ҮГ НЬ
МАХБОДООР ИЛЭРСЭН

I БОТЬ

БУРХАНЫ ИЛРЭЛТ БА АЖИЛ

ТӨГС ХҮЧИТ БУРХАНЫ ЧУУЛГАН

Зохиогчийн эрх © 2023 Төгс Хүчит Бурханы Чуулган

ҮГ НЬ
МАХБОДООР ИЛЭРСЭН
I БОТЬ
БУРХАНЫ ИЛРЭЛТ БА АЖИЛ

Эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн “Үг нь махбодоор илэрсэн” (товчоор Үг гэх) ном нь одоогийн байдлаар I Боть: Бурханы илрэлт ба ажил; II Боть: Бурханыг мэдэх тухай; III Боть: Эцсийн өдрүүдийн Христийн яриа; IV Боть: Антихристүүдийг илчлэх нь; V Боть: Удирдагч, ажилчдын үүрэг хариуцлага; VI Боть: Үнэний эрэл хайгуулын тухай гэсэн зургаан ботиос бүрддэг.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Зохиогчийн эрх эзэмшигчийн бичгээр үйлдсэн тодорхой зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийн аль нэг хэсгийг хэвлэн олшруулах, бичлэг хийх, мэдээлэл хадгалах, хайх системд оруулах зэргээр цахим эсвэл механик аливаа хэлбэрээр хуулбарлах, дамжуулахыг хориглоно.

Мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу:
contact.mn@kingdomsalvation.org

Энэхүү номын агуулгыг бүхэлд нь мэргэжлийн орчуулагчид орчуулж, хянан тохиолдуулсан хэдий ч бага зэргийн алдаа мадаг гарч болзошгүй. Хэрвээ та тийм алдаа олж харвал хятад хэл дээрх эх бичвэрээс лавлана уу. Дахин хэвлэх үед нь уг номыг шинэчлэх боломжтой тул бидэнтэй мөн холбоо бариарай.

Төгс Хүчит Бурханы Чуулган Хэвлэв
https://mn.godfootsteps.org

ӨМНӨХ ҮГ

Хэдийгээр олон хүн Бурханд итгэдэг ч Бурханд итгэх итгэл гэж юу болохыг, Бурханы хүсэлд нийцэхийн тулд юу хийх ёстойгоо цөөн хүн л ойлгодог. Яагаад гэвэл, хүмүүс “Бурхан” гэх үг, “Бурханы ажил” гэх мэт хэлцийг мэддэг боловч Бурханыг мэддэггүй, Бурханы ажлыг бүр ч мэддэггүй. Тэгэхээр, Бурханыг мэддэггүй тэр бүх хүн будилсан итгэлтэй байдагт гайхах зүйлгүй юм. Бурханд итгэх нь тэдний хувьд хэтэрхий танил бус, хэтэрхий танил бус учраас хүмүүс Бурханд итгэх итгэлийг нухацтай авч үздэггүй. Ийм байдлаар тэд Бурханы шаардлагад нийцдэггүй. Өөрөөр хэлбэл, хэрвээ хүмүүс Бурханыг мэддэггүй, Түүний ажлыг мэддэггүй бол Бурханаар ашиглуулахад тохирохгүй, Бурханы хүслийг хангаж бүр ч чадахгүй. “Бурханд итгэх итгэл” гэдэг нь Бурхан байдаг гэдэгт итгэх явдал; энэ нь Бурханд итгэх итгэлийн хамгийн энгийн ухагдахуун юм. Үүнээс гадна, Бурхан байдаг гэж итгэх нь үнэхээр Бурханд итгэхтэй адилгүй; харин ч энэ нь шашны өнгө аяс ихтэй энгийн итгэл билээ. Бурханд итгэх жинхэнэ итгэл гэдэг нь Бурхан бүх зүйлийг захирдаг хэмээх итгэлд үндэслэн Бурханы үг ба ажлыг туулж, завхарсан зан чанараасаа ангижирч, Бурханы хүслийг хангаж, Бурханыг мэдэж авна гэсэн үг юм. Ийм төрлийн аяныг л “Бурханд итгэх итгэл” хэмээн нэрлэж болно. Гэсэн ч хүмүүс Бурханд итгэх итгэлийг ихэвчлэн энгийн, хөнгөн хийсвэр асуудал гэж үздэг. Бурханд ийм маягаар итгэдэг хүмүүс Бурханд итгэхийн утга учрыг алдсан байдаг бөгөөд эцсээ хүртэл үргэлжлүүлэн итгэлээ ч гэсэн, Бурханы сайшаалыг хэзээ ч хүртэж чадахгүй, учир нь тэд буруу замаар алхаж байдаг. Өнөөдөр ч гэсэн бичиг үсгийн дагуу, хоосон сургаал дотор Бурханд итгэдэг хүмүүс бий. Өөрсдөд нь Бурханд итгэх итгэлийн мөн чанар байхгүй гэдгийг тэд мэддэггүй бөгөөд Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй. Гэсэн ч амар амгалангийн ерөөл болон арвин их нигүүлслийн төлөө Бурханд залбирсаар байдаг. Бүгдээрээ түр зогсоод, зүрх сэтгэлээ тайван байлгаж, өөрсдөөсөө ингэж асууцгаая: Бурханд итгэх нь үнэхээр газар дэлхий дээрх хамгийн амархан зүйл юм гэж үү? Бурханд итгэнэ гэдэг Бурханаас их нигүүлслийг хүлээн авахаас цаашгүй юм гэж үү? Бурханд итгэдэг боловч Түүнийг мэддэггүй, Бурханд итгэдэг ч Түүнийг эсэргүүцдэг хүмүүс Бурханы хүслийг үнэхээр хангаж чадна гэж үү?

Бурхан, хүн хоёрыг эн тэнцүү мэт ярьж болохгүй. Түүний мөн чанар болон ажил нь хүний хувьд хамгийн ойлгошгүй, мэдэхэд бэрхтэй юм. Хэрвээ Бурхан хүний ертөнцөд биечлэн Өөрийн ажлыг хийж, Өөрийн үгийг хэлээгүй бол хүн Бурханы хүслийг хэзээ ч ойлгож чадахгүй байх байлаа. Тэгвэл бүхий л амьдралаа Бурханд зориулсан хүмүүс хүртэл Түүний сайшаалыг хүртэж чадахгүй байх байв. Хэрвээ Бурхан ажиллаж эхлэхгүй бол хүн хэчнээн сайн ажиллалаа ч гэсэн, бүгд хий дэмий болно, учир нь Бурханы бодол үргэлж хүний бодлоос дээгүүр байх ба Бурханы мэргэн ухааныг хүн ойлгошгүй билээ. Иймээс Бурханыг болон Түүний ажлыг “бүрэн ойлгодог” гэж хэлдэг хүмүүс бол чадваргүй хүмүүс гэж Би хэлдэг; тэд бүгд биеэ

тоосон, мунхаг байдаг. Хүн Бурханы ажлыг тодорхойлох ёсгүй; түүнчлэн, хүн Бурханы ажлыг тодорхойлж чадахгүй. Бурханы нүдээр бол хүн шоргоолж шиг өчүүхэн юм; тэгэхээр хүн яаж Бурханы ажлыг ойлгож чадах юм бэ? “Бурхан ингэж, тэгж ажилладаггүй”, эсвэл “Бурхан ийм, тийм” хэмээн чалчих дуртай хүмүүс биеэ тоосон байдалтай ярьж байгаа бус уу? Махан биетэй хүнийг Сатан завхруулсан гэдгийг бид бүгд мэдэх ёстой. Бурханыг эсэргүүцэх нь хүн төрөлхтний уг чанар юм. Хүн төрөлхтөн Бурхантай эн зэрэгцэж чадахгүй, Бурханы ажилд зөвлөгөө өгч бүр ч чадахгүй. Бурхан хүнийг хэрхэн залж чиглүүлдгийн тухайд бол, энэ нь Бурханы Өөрийн ажил юм. Хүн ийм, тийм гэсэн үзэл бодол илэрхийлэлгүйгээр захирагдах ёстой, учир нь хүн бол тоос шороо төдий билээ. Нэгэнт бид Бурханыг эрж хайхаар зорьж байгаа тул Бурханыг бодолцож үзэг гэсэндээ Бурханы ажилд өөрсдийн үзлийг нэмэх ёсгүй, тэр ч байтугай Бурханы ажлыг зориуд эсэргүүцэхийн тулд завхарсан зан чанараа чадлынхаа хэрээр ашиглах ёсгүй. Тэгвэл бид антихристүүд болох бус уу? Тийм хүмүүс яаж Бурханд итгэж чадах юм бэ? Бид Бурхан байдаг гэдэгт итгэдэг, Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, Түүнийг харахыг хүсдэг учраас үнэний замыг эрэлхийлэх ёстой ба Бурхантай нийцэлтэй байх замыг хайх ёстой. Бид Бурханыг зөрүүдлэн эсэргүүцэж зогсох ёсгүй. Тийм үйлдлээс ямар сайн үр дагавар гарах юм бэ?

Өнөөдөр Бурхан шинэ ажил хийсэн. Чи эдгээр үгийг хүлээн зөвшөөрч чадахгүй байж магад, тэдгээр нь чамд хачин санагдаж магад боловч төрөлхийн чанараа бүү илчил гэж Би чамд зөвлөе, учир нь Бурханы өмнө зөвт байдлын төлөө үнэхээр өлсөж цангадаг хүмүүс л үнэнийг олж авч чадах ба үнэхээр үнэн сүсэгт хүмүүсийг л Бурхан гэгээрүүлж, залж чиглүүлж чадна. Хэрүүл маргаанаар биш, тайван тогтуунаар үнэнийг эрж хайснаар үр дүнд хүрдэг. “Өнөөдөр Бурхан шинэ ажил хийсэн” гэж Би хэлэхдээ Бурхан махбодод эргэн ирсэн явдлыг хэлж байгаа юм. Магадгүй эдгээр үгийг чи тоодоггүй байх; магадгүй чи тэдгээрийг үзэн яддаг; эсвэл магадгүй асар их сонирхдог байх. Ямартай ч, Бурханы илрэлтийг үнэхээр хүсэн хүлээдэг бүх хүн яаран дүгнэлт гаргахын оронд энэ баримттай нүүр тулж, няхуур шинжлэн үзэж чадна гэж Би найдаж байна; энэ бол ухаалаг хүний хийх ёстой зүйл юм.

Ийм зүйлийг судалж шинжлэх нь хэцүү биш боловч бид дор бүрнээ энэ нэг үнэнийг мэдэх шаардлагатай байдаг: Бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы мөн чанарыг эзэмшинэ, бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы илэрхийллийг эзэмшинэ. Бурхан махбод болдог тул хийхээр зорьж буй ажлаа авчирна, мөн Бурхан махбод болдог тул Өөрийн юу болохыг илэрхийлж, хүнд үнэнийг авчирч, амь хайрлаж, замыг заан харуулж чадна. Бурханы мөн чанаргүй махбод нь бие махбодтой болсон Бурхан лавтайяа биш; үүнд эргэлзэх зүйл үгүй. Хэрвээ хүн, Бурханы махбод болсон бие мөн эсэхийг судалж шинжлэхээр зорьж байгаа бол Түүний илэрхийлдэг зан чанар, хэлдэг үгээс үүнийг нотлох ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон бие мөн эсэх, үнэн зам мөн эсэхийг нотлохын тулд хүн Түүний мөн чанарт үндэслэн ялган таних ёстой. Иймээс

Бурханы махбод болсон бие мөн эсэхийг тодорхойлох гол түлхүүр нь гадаад дүр төрхөөс илүүтэйгээр Түүний мөн чанарт (Түүний ажил, Түүний айлдвар, Түүний зан чанар болон өөр олон талд) оршдог. Хэрвээ хүн Түүний гадаад дүр төрхийг л шинжлээд, үүний үр дүнд мөн чанарыг нь орхигдуулбал хүн харанхуй бүдүүлэг, мунхаг гэдгийг энэ нь харуулдаг. Гадаад дүр төрх нь мөн чанарыг тодорхойлж чадахгүй; түүгээр ч үл барам, Бурханы ажил хэзээ ч хүний үзэлтэй нийцэхгүй. Есүсийн гадаад дүр төрх хүний үзэлтэй зөрчилдөөгүй гэж үү? Түүний төрх байдал болон хувцаслалт жинхэнэ ялгамж чанарынх нь талаар ямар нэг сэжүүр өгч чадаагүй бус уу? Эртний фарисайчууд Есүсийн гадаад дүр төрхийг л харж, хэлсэн үгийг нь үнэн сэтгэлээсээ авч үзээгүйгээс болоод Түүнийг эсэргүүцсэн биш үү? Бурханы илрэлтийг эрж хайдаг ах эгч нар нэг бүр түүхийн эмгэнэлт явдлыг давтахгүй гэж Би найдаж байна. Та нар орчин үеийн фарисайчууд болж, Бурханыг загалмайд дахин цовдлох ёсгүй. Бурханыг эргэн ирэхэд хэрхэн угтан авахаа анхааралтай бодолцон үзэж, хэрхэн үнэнд захирагддаг хүн байх тухай тодорхой мэдэж байх ёстой. Есүс үүл хөлөглөн эргэн ирэхийг хүлээж байгаа хүн бүрийн хариуцлага энэ билээ. Бид сүнсний нүдээ арчиж цэвэрлэн, хэтрүүлэгтэй уран зөгнөлийн үгэнд автахгүй байх ёстой. Бурханы бодитой ажлын талаар бодож, Бурханы бодит талыг харах ёстой. Эзэн Есүс үүл хөлөглөн, та нарын дунд гэнэт бууж ирээд, Өөрийг нь хэзээ ч мэдээгүй, хараагүй, Өөрийнх нь хүслийг хэрхэн биелүүлэхээ мэддэггүй та нарыг авах тэр өдрийг үргэлж хүсэн хүлээж, сэтгэл хөдлөлдөө бүү авт, эсвэл мөрөөдөлдөө бүү умба. Бодитой хэрэг явдлыг бодсон чинь дээр!

Чи судлах зорилгоор, эсвэл хүлээн зөвшөөрөх санаатайгаар энэ номыг нээсэн байж магадгүй; хандлага чинь ямар ч байлаа гэсэн үүнийг дуустал нь уншиж, амархан хойш тавихгүй гэж Би найдаж байна. Магадгүй, эдгээр үгийг уншсаны дараа хандлага чинь өөрчлөгдөнө, гэхдээ тэр нь чиний сэдэл, ойлголтын түвшнээс хамаардаг. Гэвч, чиний мэдэх ёстой нэг зүйл бий: Бурханы үгийг хүний үг болгож болохгүй, хүний үгийг Бурханы үг болгож бүр ч болохгүй. Бурханы ашигладаг хүн бол бие махбодтой болсон Бурхан биш, бие махбодтой болсон Бурхан бол Бурханы ашигладаг хүн биш. Энд мөн чанарын ялгаа бий. Эдгээр үгийг уншсаныхаа дараа чи тэдгээрийг Бурханы үг гэж биш, зүгээр л хүний олж авсан гэгээрэл хэмээн хүлээн зөвшөөрч магадгүй. Тэр тохиолдолд чи мэдлэггүй байдлаас болж сохорсон байна. Бурханы үг яаж хүний олж авсан гэгээрэлтэй адил байж болох юм бэ? Бие махбодтой болсон Бурханы үг шинэ эрин үеийг эхлүүлж, бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлж, нууцуудыг илчилж, шинэ эрин үед барих чиглэлийг нь хүнд харуулдаг. Хүний олж авсан гэгээрэл нь хэрэгжүүлэлтийн энгийн заавар буюу мэдлэг төдий юм. Энэ нь бүх хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү замчилж, эсвэл Бурханы Өөрийн нууцыг илчилж чадахгүй. Эцсийн эцэст Бурхан бол Бурхан, хүн бол хүн. Бурханд Бурханы мөн чанар байдаг ба хүнд хүний мөн чанар байдаг. Хэрвээ хүн Бурханы хэлсэн үгийг зүгээр л Ариун Сүнсний энгийн гэгээрэл гэж үзээд, элчүүд болон эш үзүүлэгчдийн үгийг Бурханы биечлэн хэлсэн

үг гэж авч үзэх юм бол тэр нь хүний алдаа юм. Ямар ч байсан чи хэзээ ч зөв бурууг хольж, өндрийг нам болгож, гүн гүнзгийг өнгөц гэж эндүүрэх ёсгүй; ямар ч байсан чи үнэн гэдгийг нь мэддэг зүйлээ хэзээ ч зориуд няцаах ёсгүй. Бурхан байдаг гэж итгэдэг хүн бүр асуудлыг зөв байр сууриас шинжилж, Бурханы бүтээлийн өнцгөөс Түүний шинэ ажил болон үгийг хүлээн зөвшөөрөх ёстой; эс бөгөөс тэднийг Бурхан таягдан хаяна.

Еховагийн ажлын дараа, Өөрийн ажлыг хүмүүсийн дунд хийхийн тулд Есүс махбод болсон. Түүний ажил тусдаа хэрэгжээгүй, харин Еховагийн ажилд тулгуурласан юм. Энэ нь, Хуулийн эрин үеийг төгсгөснийхөө дараа Бурханы хийсэн шинэ эрин үеийн ажил байв. Үүнтэй адилаар, Есүсийн ажил дууссаны дараа Бурхан дараагийн эрин үеийн ажлаа үргэлжлүүлсэн, учир нь Бурханы бүхий л удирдлага үргэлж урагшилж байгаа. Хуучин эрин үе өнгөрөх үедээ шинэ эрин үеэр солигдох ба хуучин ажил дуусмагц Бурханы удирдлагыг үргэлжлүүлэх шинэ ажил байх болно. Энэ удаад бие махбодтой болсон нь Есүсийн ажил дууссаны дараа Бурхан хоёр дахь удаа бие махбод болсон хэрэг юм. Мэдээж, энэ удаа бие махбодтой болсон нь бие даан тусдаа тохиолддоггүй; харин энэ нь Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үеийн дараах, ажлын гурав дахь үе шат юм. Бурхан ажлын шинэ үе шатыг эхлэх бүрд үргэлж шинэ эхлэл байх ёстой, мөн ердөө шинэ эрин үеийг авчрах ёстой. Иймээс Бурханы зан чанар, Түүний ажиллах арга зам, ажлын байршил болон Түүний нэрэнд ч гэсэн харгалзах өөрчлөлтүүд гардаг. Тиймээс хүний хувьд, шинэ эрин үе дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдагт гайхах зүйлгүй. Гэхдээ Өөрийг нь хүн хэрхэн эсэргүүцэхээс үл хамааран Бурхан үргэлж Өөрийн ажлыг хийж, бүх хүн төрөлхтнийг урагш хөтөлж байгаа. Есүс хүний ертөнцөд ирэх үедээ Нигүүлслийн эрин үеийг эхлүүлж, Хуулийн эрин үеийг төгсгөсөн. Эцсийн өдрүүдэд Бурхан дахин нэг удаа махбод болсон ба энэ удаа бие махбодтой болохдоо Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Хаанчлалын эрин үеийг эхлүүлсэн юм. Хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханыг хүлээн авч чаддаг бүх хүн Хаанчлалын эрин үе рүү хүргэгдэж, Бурханы удирдамжийг биечлэн хүлээн авч чадна. Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан. Иймээс хүний нүгэл уучлагдсаны дараа Бурхан хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтлөхийн тулд махбодод эргэн ирж, гэсгээлт, шүүлтийн ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажил нь хүнийг илүү өндөр хүрээнд аваачсан. Түүний ноёрхол дор захирагддаг бүх хүн илүү өндөр үнэнийг эдэлж, илүү агуу ерөөлийг хүлээн авна. Тэд үнэхээр гэрэлд амьдарч, үнэн, зам, амийг олж авна.

Хэрвээ хүмүүс Нигүүлслийн эрин үед гацаж үлдвэл Бурханы төрөлх зан чанарыг мэдэх нь бүү хэл, өөрсдийн завхарсан зан чанараас хэзээ ч ангижрахгүй.

Хүмүүс үргэлж арвин их нигүүлслийн дунд амьдардаг мөртөө Бурханыг мэдэж, Бурханыг сэтгэл хангалуун байлгах боломжийг өөрсдөд нь олгодог амийн замгүй байдаг бол итгэлдээ Бурханыг үнэхээр олж авч хэзээ ч чадахгүй. Энэ төрлийн итгэл үнэхээр өрөвдөлтэй. Энэ номыг уншиж дуусаад, Хаанчлалын эрин үед бие махбодтой болсон Бурханы ажлын алхам бүрийг туулсан үедээ чи олон жил тээсэн итгэл найдвар чинь эцэстээ биелснийг мэдрэх болно. Одоо л чи Бурханыг үнэхээр нүүр тулан харсан гэдгээ мэдэрнэ; одоо л Бурханы царайг ширтэж, Бурханы хувийн айлдварыг сонсож, Бурханы ажлын мэргэн ухааныг ойлгож, Бурхан хэчнээн бодитой бөгөөд төгс хүчтэй болохыг үнэхээр мэдэрсэн гэж чамд санагдана. Өнгөрсөн үеийн хүмүүсийн хэзээ ч харж, эзэмшиж байгаагүй олон зүйлийг олж авсан гэдгээ чи мэдэрнэ. Энэ үед чи Бурханд итгэх гэж юу болох, Бурханы хүсэлд нийцэх гэж юу болох талаар тодорхой мэднэ. Мэдээж, хэрвээ чи өнгөрсөн үеийн үзэл бодолтой зууралдаж, хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханы тухай баримтыг голж, эсвэл үгүйсгэвэл юу ч олж авалгүй гар хоосон үлдээд, эцэст нь Бурханыг эсэргүүцсэн гэмтэй гэж хэлүүлнэ. Үнэнийг дуулгавартай дагаж, Бурханы ажилд захирагддаг хүмүүс хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурхан—Төгс Хүчитийн нэрэн дор орно. Тэд Бурханы хувийн удирдамжийг хүлээн авч, илүү их, илүү өндөр үнэнийг олж авч, бас жинхэнэ амьдралыг хүлээн авч чадна. Тэд өнгөрсөн үеийн хүмүүсийн хэзээ ч харж байгаагүй үзэгдлийг харна: “Би өөртэй минь ярьсан хоолойн зүг эргэж харахад долоон алтан дэнгийн суурийг үзэв; долоон алтан дэнгийн суурийн голд нь хөлөө хүрсэн өмсгөлтэй, алтан бүсээр цээжээ бүсэлсэн хүний Хүүгийн дүртэй Нэгэн зогсож байв. Түүний толгой болон үс нь ноос мэт, цас мэт цав цагаан; нүд нь галын дөл мэт; хөл нь зууханд шатааж өнгөлсөн гууль адил; дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэрээр баруун гартаа долоон од барьсан: амнаас нь хоёр талдаа хурц иртэй илд гарсан: царайг нь харвал хурц нар мэт гэрэлтэж байв” (Илчлэл 1:12–16). Энэ үзэгдэл нь Бурханы бүхий л зан чанарын илэрхийлэл бөгөөд Түүний бүхий л зан чанарын илэрхийлэл нь бас энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажлын илэрхийлэл юм. Гэсгээлт, шүүлтийн урсгалд хүний Хүү айлдвараараа дамжуулан төрөлх зан чанараа илэрхийлж, Түүний гэсгээлт, шүүлтийг хүлээн авдаг бүх хүнд хүний Хүүгийн жинхэнэ царайг харах боломж олгодог нь Иоханы харсан хүний Хүүгийн нүүр царайн үнэн зөв дүрслэл юм. (Мэдээж, Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлыг хүлээн авдаггүй хүмүүст энэ бүхэн үзэгдэхгүй.) Хүний хэлийг ашиглан Бурханы жинхэнэ нүүр царайг бүрэн илэрхийлж чадахгүй тул Бурхан Өөрийн жинхэнэ царайг хүнд харуулахын тулд төрөлх зан чанараа илэрхийлэх аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, хүний Хүүгийн төрөлх зан чанарыг ойлгосон бүх хүн нь хүний Хүүгийн жинхэнэ царайг харсан билээ, учир нь Бурхан дэндүү агуу бөгөөд хүний хэлээр бүрэн илэрхийлэх аргагүй. Хүн Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлын алхам бүрийг туулмагцаа дэнгүүдийн дундах хүний Хүүгийн талаар хэлсэн Иоханы үгийн жинхэнэ утгыг мэднэ: “Түүний толгой болон үс нь ноос мэт, цас мэт цав

цагаан; нүд нь галын дөл мэт; хөл нь зууханд шатааж өнгөлсөн гууль адил; дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэрээр баруун гартаа долоон од барьсан: амнаас нь хоёр талдаа хурц иртэй илд гарсан: царайг нь харвал хурц нар мэт гэрэлтэж байв.” Тэр үед чи, маш олон үг хэлсэн энэ эгэл махбод нь хоёр дахь удаа бие махбод болсон Бурхан гарцаагүй мөн гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр мэднэ. Түүнчлэн, хэчнээн их ерөөгдсөнөө үнэхээр мэдэрч, хамгийн хувьтай хүн гэдгээ мэдэрнэ. Чи энэхүү ерөөлийг хүлээн авахыг хүсэхгүй байна гэж үү?

Энэ номын эхний хэсэг нь “Христийн эхэн үеийн айлдварууд” юм. Эдгээр үг Нигүүлслийн эрин үеийн төгсгөлөөс Хаанчлалын эрин үеийн эхлэл дэх шилжилтийг төлөөлдөг бөгөөд хүний Хүүгийн тухай чуулгануудад хийсэн Ариун Сүнсний ил тод гэрчлэл юм. Түүнчлэн “Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун” гэх Илчлэлийн үгийн биелэл энэ билээ. Энэ бол Хаанчлалын эрин үед Бурханы эхэлсэн ажил юм. Номны хоёрдугаар хэсэг нь, албан ёсоор Өөрийгөө илчилсний дараа хүний Хүүгийн биечлэн хэлсэн үг юм. Энэ нь зөгнөл, нууцуудын илчлэл, амийн зам гэх мэт хэд хэдэн төрлийн үг, айлдварыг агуулдаг бөгөөд агуулга нь нэлээд баялаг—хаанчлалын ирээдүйн тухай зөгнөл, Бурханы удирдлагын төлөвлөгөөний нууцын илчлэл, хүний уг чанарын дүн шинжилгээ, ятгалга, анхааруулга, хатуу ширүүн шүүлт, үнэн сэтгэлийн тайтгарлын үгс, амьдралын тухай хэлэлцүүлэг, оролтын тухай яриа гэх мэт байдаг. Товчхондоо, Бурханд юу байгаа болон Тэр юу болох, Бурханы зан чанар нь бүгд Түүний ажил болон үгээр илэрхийлэгддэг. Мэдээж, энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь үндсэндээ гэсгээлт, шүүлтээр дамжуулан Өөрийн зан чанарыг илэрхийлэх явдал юм. Энэ сууринд үндэслээд Тэрээр хүнд илүү их үнэнийг авчирч, хэрэгжүүлэлтийн илүү олон замыг заан үзүүлж, улмаар хүнийг байлдан дагуулж, завхарсан зан чанараас нь аврах зорилгодоо хүрдэг. Энэ бол Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлын ард оршдог зүйл юм. Чи шинэ эрин үед орохыг хүсэж байна уу? Завхарсан зан чанараасаа ангижрахыг хүсэж байна уу? Илүү өндөр үнэнийг олж авахыг хүсэж байна уу? Хүний Хүүгийн жинхэнэ царайг харахыг хүсэж байна уу? Энэ амьдралаа утга учиртай байлгахыг хүсэж байна уу? Бурханаар төгс болгуулахыг хүсэж байна уу? Тэгвэл чи Есүсийн эргэн ирэлтийг хэрхэн угтан авах гэж байна вэ?

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ
ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД
ЧУУЛГАНУУДАД ХАНДСАН АРИУН СҮНСНИЙ ҮГ

(1991 ОНЫ 2-Р САРЫН 11—1991 ОНЫ 11-Р САРЫН 20)

Оршил 2

1-р бүлэг 8
2-р бүлэг 9
3-р бүлэг 10
4-р бүлэг 11
5-р бүлэг 12
6-р бүлэг 13
7-р бүлэг 14
8-р бүлэг 15
9-р бүлэг 18
10-р бүлэг 20
11-р бүлэг 21
12-р бүлэг 22
13-р бүлэг 24
14-р бүлэг 28
15-р бүлэг 31
16-р бүлэг 33
17-р бүлэг 34
18-р бүлэг 36
19-р бүлэг 37
20-р бүлэг 40
21-р бүлэг 42
22-р бүлэг 43
23-р бүлэг 45
24-р бүлэг 46
25-р бүлэг 46
26-р бүлэг 47
27-р бүлэг 48
28-р бүлэг 49
29-р бүлэг 50
30-р бүлэг 51

31-р бүлэг 52
32-р бүлэг 53
33-р бүлэг 53
34-р бүлэг 54
35-р бүлэг 57
36-р бүлэг 59
37-р бүлэг 60
38-р бүлэг 62
39-р бүлэг 63
40-р бүлэг 64
41-р бүлэг 64
42-р бүлэг 66
43-р бүлэг 67
44-р бүлэг 68
45-р бүлэг 69
46-р бүлэг 70
47-р бүлэг 72
48-р бүлэг 73
49-р бүлэг 74
50-р бүлэг 75
51-р бүлэг 76
52-р бүлэг 77
53-р бүлэг 78
54-р бүлэг 79
55-р бүлэг 80
56-р бүлэг 81
57-р бүлэг 83
58-р бүлэг 84
59-р бүлэг 85
60-р бүлэг 86
61-р бүлэг 87
62-р бүлэг 89
63-р бүлэг 91
64-р бүлэг 93
65-р бүлэг 95
66-р бүлэг 97
67-р бүлэг 98
68-р бүлэг 99
69-р бүлэг 101
70-р бүлэг 103

71-р бүлэг 105
72-р бүлэг 107
73-р бүлэг 109
74-р бүлэг 111
75-р бүлэг 112
76-р бүлэг 114
77-р бүлэг 117
78-р бүлэг 119
79-р бүлэг 122
80-р бүлэг 124
81-р бүлэг 127
82-р бүлэг 130
83-р бүлэг 133
84-р бүлэг 135
85-р бүлэг 138
86-р бүлэг 142
87-р бүлэг 143
88-р бүлэг 146
89-р бүлэг 149
90-р бүлэг 151
91-р бүлэг 154
92-р бүлэг 157
93-р бүлэг 160
94-р бүлэг 162
95-р бүлэг 165
96-р бүлэг 169
97-р бүлэг 172
98-р бүлэг 175
99-р бүлэг 179
100-р бүлэг 183
101-р бүлэг 186
102-р бүлэг 189
103-р бүлэг 193
104-р бүлэг 196
105-р бүлэг 199
106-р бүлэг 202
107-р бүлэг 206
108-р бүлэг 209
109-р бүлэг 213
110-р бүлэг 217

111-р бүлэг 220
112-р бүлэг 224
113-р бүлэг 228
114-р бүлэг 231
115-р бүлэг 234
116-р бүлэг 237
117-р бүлэг 240
118-р бүлэг 242
119-р бүлэг 245
120-р бүлэг 248

ХОЁРДУГААР ХЭСЭГ

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД

(1992 ОНЫ 2-Р САРЫН 20—1992 ОНЫ 6-Р САРЫН 1)

Оршил 253

1-р бүлэг 254
2-р бүлэг 256
3-р бүлэг 257
4-р бүлэг 259
5-р бүлэг 262
6-р бүлэг 265
7-р бүлэг 268
8-р бүлэг 270
9-р бүлэг 273
10-р бүлэг 276
Хаанчлалын сүлд дуулал 280
11-р бүлэг 282
12-р бүлэг 285
13-р бүлэг 288
14-р бүлэг 291
15-р бүлэг 293
16-р бүлэг 297
17-р бүлэг 300
18-р бүлэг 303
19-р бүлэг 306
20-р бүлэг 310

21-р бүлэг 313
22-р бүлэг 316
23-р бүлэг 319
24-р бүлэг 323
25-р бүлэг 326
Хүмүүс ээ, бүгд баярлан хөөрцгөө! 329
26-р бүлэг 330
27-р бүлэг 333
28-р бүлэг 337
29-р бүлэг 340
30-р бүлэг 343
31-р бүлэг 346
32-р бүлэг 349
33-р бүлэг 353
34-р бүлэг 356
35-р бүлэг 359
36-р бүлэг 363
37-р бүлэг 366
38-р бүлэг 368
39-р бүлэг 371
40-р бүлэг 374
41-р бүлэг 378
42-р бүлэг 381
43-р бүлэг 384
44-р бүлэг 387
45-р бүлэг 390
46-р бүлэг 394
47-р бүлэг 397

ХАВСРАЛТ

“БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД”-ЫН НУУЦЫН ТУХАЙ ТАЙЛБАР

1-р бүлэг 402
3-р бүлэг 406
4-р бүлэг 411
5-р бүлэг 417
6-р бүлэг 421
Петрийн амьдралын тухайд 427

8-р бүлэг 432
9-р бүлэг 435
Нэмэлт: 1-р бүлэг 441
10-р бүлэг 443
11-р бүлэг 448
Нэмэлт: 2-р бүлэг 453
12-р бүлэг 455
13-р бүлэг 462
14-р бүлэг 465
15-р бүлэг 470
16-р бүлэг 475
17-р бүлэг 480
18-р бүлэг 486
19-р бүлэг 490
20-р бүлэг 494
21-р бүлэг 498
22-р бүлэг ба 23-р бүлэг 500
24-р бүлэг ба 25-р бүлэг 505
26-р бүлэг 508
27-р бүлэг 512
28-р бүлэг 516
29-р бүлэг 519
30-р бүлэг 522
31-р бүлэг 527
32-р бүлэг 529
33-р бүлэг 533
35-р бүлэг 536
36-р бүлэг 540
38-р бүлэг 545
39-р бүлэг 549
40-р бүлэг 551
41-р бүлэг 554
42-р бүлэг 559
44-р бүлэг ба 45-р бүлэг 563
46-р бүлэг 565

ГУРАВДУГААР ХЭСЭГ
ЧУУЛГАНУУДААР ЯВАХДАА ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ

(1992 ОНЫ 6-Р САР—2010 ОНЫ 3-Р САРЫН 23)

Оршил 569

I

(1992 ОНЫ 6-Р САР—1992 ОНЫ 10-Р САР)

Зам… 1 575
Зам… 2 578
Зам… 3 581
Зам… 4 585
Зам… 5 588
Зам… 6 592
Зам… 7 596
Зам… 8 600
Итгэгчид ямар үзэл бодолтой байх учиртай вэ 604
Бурханы ажлын алхмуудын тухай 606
Ялзарсан хүн Бурханыг төлөөлж чадахгүй 607
Шашны үйлчлэлээс ангижрах ёстой 609
Бурханд итгэхдээ Бурханыг дуулгавартай дагах ёстой 612
Бурхантай хэвийн харилцаа тогтоох нь маш чухал 614
Хэвийн сүнслэг амьдрал хүнийг зөв зам руу хөтөлдөг 618
Төгс болгуулсан хүмүүст өгөх амлалт 620
Хорон муу хүмүүс гарцаагүй шийтгүүлнэ 624
Хэвийн байдалд хэрхэн орох вэ 627
Хэрхэн Бурханы хүсэлд нийцүүлэн үйлчлэх вэ 629
Бодит байдлыг хэрхэн мэдэх тухай 633
Хэвийн сүнслэг амьдралын талаар 636
Чуулганы амьдрал ба бодит амьдралыг хэлэлцэх нь 639
Хүн бүр үүргээ гүйцэтгэх тухай 644
Бурхан хүнийг ашиглах талаар 646
Та нар үнэнийг ойлгомогцоо хэрэгжүүлэх ёстой 647
Аврал хүрдэг хүн бол үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг хүн юм 650
Шаардлага хангадаг хоньчны эзэмшвэл зохих зүйл 654
Туршлагын талаар 655
Шинэ эрин үеийн тушаал 658

Мянган жилийн хаанчлал ирчихсэн 661
Бурхантай харилцах харилцаа чинь ямар вэ? 664
Бодит байдалд илүү анхаар 669
Тушаалуудыг мөрдөж, үнэнийг хэрэгжүүлэх нь 674
Бодитой Бурхан бол Бурхан Өөрөө гэдгийг чи мэдэх ёстой 677
Үнэнийг хэрэгжүүлэх нь л бодит байдалтай болж байгаа хэрэг 681
Бурханы өнөөдрийн ажлыг мэдэх нь 685
Бурханы ажил хүний төсөөлдөг шиг энгийн үү? 691
Чи Бурханд итгэдэг тул үнэний төлөө амьдрах учиртай 694
Долоон Аянгын Нүргээн—Хаанчлалын сайн мэдээ ертөнц даяар тархахыг зөгнөж байна 696
Бие махбодтой болсон Бурхан болон Бурханы ашигладаг хүмүүсийн хоорондох үндсэн ялгаа 699
Харанхуйн нөлөөнөөс ангижир, тэгвэл чи Бурханаар авхуулна 705
Бурханд итгэхдээ шашны зан үйлд биш бодит байдалд анхаарлаа хандуулах ёстой 709
Бурханы өнөөдрийн ажлыг мэддэг хүмүүс л Бурханд үйлчилж болно 711
Бурханыг хайрлах жинхэнэ хайр аяндаа төрдөг 716
Залбирлыг хэрэгжүүлэх тухай 721
Бурханы шинэхэн ажлыг мэдэж, Түүний мөрийг дага 726
Зан чанар нь өөрчлөгдсөн хүмүүс бол Бурханы үгийн бодит байдалд орсон хүмүүс юм 735
Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгах тухай 741
Төгс төгөлдөрт хүрэхийн тулд Бурханы хүслийг анхаар 745
Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүмүүсийг Бурхан төгс болгодог 751
Бурханд үнэнч зүрх сэтгэлээр дуулгавартай байдаг хүмүүсийг Бурхан гарцаагүй олж авна 755
Хаанчлалын эрин үе бол үгийн эрин үе юм 760
Бүгд Бурханы үгээр биелдэг 768
Бурханы бодит байдалд туйлын дуулгавартай байж чаддаг хүмүүс бол Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс юм 778
Төгс болгуулах хүмүүс цэвэршүүлэлт туулах ёстой 784
Зовлонт шалгалтыг туулснаар л Бурханы хайр татам байдлыг мэдэж болно 795
Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг 801
“Мянган жилийн хаанчлал ирчихсэн” тухай товч яриа 809
Бурханыг мэддэг хүмүүс л түүнд гэрчлэл хийж чадна 812
Петр Есүсийг хэрхэн мэдэж авсан тухай 818
Хүн цэвэршүүлэлтийг туулж байж л жинхэнэ хайрыг олж авч чадна 827
Бурханыг хайрладаг хүмүүс Түүний гэрэлд үүрд амьдарна 831
Хэрэгжүүлэлтэд анхаардаг хүмүүс л төгс болгуулж чадна 839

Ариун Сүнсний ажил ба Сатаны ажил 845
Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүст өгөх анхааруулга 850
Чи Бурханд өгсөн үнэнч байдлаа хадгалах ёстой 855
Чи амилсан хүн мөн үү? 863
Зан чанар чинь өөрчлөгдөхгүй байх нь Бурханд дайсагнаж буй хэрэг 866
Бурханыг мэддэггүй бүх хүн бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм 871

II

(1992 ОНЫ 11-Р САР—1993 ОНЫ 6-Р САР)

Ажил ба оролт 1 878
Ажил ба оролт 2 880
Ажил ба оролт 3 884
Ажил ба оролт 4 889
Ажил ба оролт 5 893
Ажил ба оролт 6 898
Ажил ба оролт 7 904
Ажил ба оролт 8 910
Ажил ба оролт 9 916
Ажил ба оролт 10 922
Бурханы ажлын үзэгдэл 1 930
Бурханы ажлын үзэгдэл 2 934
Бурханы ажлын үзэгдэл 3 941
Библийн талаар 1 956
Библийн талаар 2 964
Библийн талаар 3 967
Библийн талаар 4 973
Хэрэгжүүлэлт 1 977
Хэрэгжүүлэлт 2 987
Бие махбодтой болохын нууц 1 992
Бие махбодтой болохын нууц 2 1004
Бие махбодтой болохын нууц 3 1009
Бие махбодтой болохын нууц 4 1016
Хоёр удаа бие махбодтой болох нь бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцээдэг 1030
Гурвал оршин байдаг уу? 1037
Хэрэгжүүлэлт 3 1047
Хэрэгжүүлэлт 4 1052
Хэрэгжүүлэлт 5 1057

Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн 1 1061
Чи яагаад товойлгогч байхыг хүсдэггүй юм бэ? 1070
Байлдан дагуулалтын ажлын хоёр дахь алхам хэрхэн үр дүнд хүрдэг вэ 1082
Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн 2 1089
Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн 3 1094
Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн 4 1102
Хэрэгжүүлэлт 6 1107
Хэрэгжүүлэлт 7 1113
Хэрэгжүүлэлт 8 1126
Израильчууд шиг үйлчил 1129
Хэв чанарыг өсгөх нь Бурханы авралыг хүлээн авахын төлөө юм 1135
Моабын үр удмыг аврахын ач холбогдол 1138
Петрийн туршлага: гэсгээлт, шүүлтийн талаарх түүний мэдлэг 1151
Та нар ажлыг ойлгох ёстой—төөрөлдсөн байдлаар бүү дага! 1170
Чи замын сүүлчийн хэсэгт яаж алхах ёстой вэ? 1175

III

(1993 ОНЫ 7-Р САР—1994 ОНЫ 3-Р САР)

Чи ирээдүйн үүрэгтээ хэрхэн хандах ёстой вэ? 1186
Хүн төрөлхтнийг удирдахын зорилго 1187
Хүний мөн чанар ба ялгамж чанар 1189
Хүний төрөлхийн ялгамж чанар болон үнэ цэн яг ямархуу вэ? 1192
Суралцдаггүй агаад мэдлэггүй хэвээр үлддэг хүмүүс: Тэд араатан биш гэж үү? 1193
Хятадын сонгогдсон хүмүүс Израилийн ямар ч овгийг төлөөлөх чадваргүй 1196
Ерөөлүүдийг та нар юу гэж ойлгодог вэ? 1197
Бурханы тухай чиний ойлголт юу вэ? 1200
Жинхэнэ хүн байхын утга учир 1205
Чи итгэлийн талаар юу мэдэх вэ? 1209
Унаж буй навчис үндэс рүүгээ буцахад чи өөрийн хийсэн ёрын муу бүхэндээ харамсана 1214
Махан биетэй хэн ч уур хилэнгийн өдрөөс зугтаж чадахгүй 1219
Аврагч аль хэдийн “цагаан үүлэн” дээр эргэн ирсэн 1224
Сайн мэдээ түгээх ажил нь бас хүнийг аврах ажил мөн 1228
Та нар бүгд маш жудаггүй! 1232
Хуулийн эрин үе дэх ажил 1236
Золин авралын эрин үеийн ажлын цаад үнэн түүх 1240
Хөгшин залуу хүмүүст зориулсан үг 1244

Бүх хүн төрөлхтөн өнөөг хүртэл хэрхэн хөгжсөнийг чи мэдэх ёстой 1250
Нэршил болон ялгамж чанарын талаар 1264
Төгс болгуулсан хүмүүс л утга учиртай амьдралаар амьдарч чадна 1278
Та нар байр суурийн ерөөлийг хойш тавьж, хүнийг аврах Бурханы хүслийг ойлгох ёстой 1286
Өөрийн үзлээр Бурханыг хязгаарласан хүн Бурханы илчлэлийг хүлээн авч яахан чадах билээ? 1293
Бурханыг болон Бурханы ажлыг мэддэг хүмүүс л Түүнийг сэтгэл хангалуун байлгаж чадна 1297
Бие махбодтой болсон Бурханы үйлчлэл ба хүний үүргийн ялгаа 1304
Бурхан бол бүх бүтээлийн эзэн 1312
Арван гурван захидлын талаар чи ямар хандлага баримталдаг вэ? 1317
Амжилт эсвэл бүтэлгүйтэл нь хүний алхдаг замаас хамаардаг 1322
Бурханы ажил ба хүний ажил 1336
Бурханы ажлын гурван үе шатыг мэдэх нь Бурханыг мэдэх зам юм 1353
Завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон Бурханы аврал илүү их хэрэгтэй 1368
Бурханы оршдог махбодын мөн чанар 1383
Бурханы ажил ба хүний хэрэгжүүлэлт 1395
Христийн мөн чанар бол Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд дуулгавартай байх явдал юм 1411
Хүний хэвийн амьдралыг сэргээж, түүнийг гайхалтай сайхан хүрэх газарт аваачих нь 1418
Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно 1435

IV

(1994—2010 ОНЫ 3-Р САРЫН 23)

Есүсийн сүнслэг биеийг харах үед чинь Бурхан тэнгэр, газрыг шинээр бүтээсэн байх болно 1451
Христтэй нийцдэггүй хүмүүс гарцаагүй Бурханыг эсэргүүцэгчид юм 1455
Дуудагддаг нь олон ч сонгогддог нь цөөхөн 1458
Чи Христтэй нийцэлтэй байх замыг эрж хайх ёстой 1461
Чи Бурханы жинхэнэ итгэгч мөн үү? 1465
Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг 1468
Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийснийг чи мэдсэн үү? 1472
Эцсийн өдрүүдийн Христ л хүнд мөнх амийн замыг өгч чадна 1475
Хүрэх газрынхаа төлөө хангалттай сайн үйл бэлд 1480
Чи хэнд үнэнч вэ? 1483

Хүрэх газрын тухай 1486
Гурван сануулга 1489
Гэм буруу нь хүнийг там руу хөтөлнө 1492
Бурханы зан чанарыг ойлгох нь маш чухал 1496
Газар дээрх Бурханыг хэрхэн мэдэх вэ 1500
Тун ноцтой асуудал: Урвалт 1 1505
Тун ноцтой асуудал: Урвалт 2 1508
Та нар үйл хэргээ бодолцож үзэх учиртай 1511
Бурхан бол хүний амийн эх сурвалж 1515
Төгс Хүчитийн санаа алдалт 1518
Хаанчлалын эрин үед Бурханы сонгосон хүмүүсийн дуулгавартай дагах ёстой захиргааны арван зарлиг 1521

Хавсралт 1: Бурханы илрэлт шинэ эрин үеийг авчирсан 1523
Хавсралт 2: Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг 1526
Хавсралт 3: Хүн Бурханы удирдлага дунд л аврагдаж чадна 1531
Хавсралт 4: Бурханы шүүлт, гэсгээлтээс илрэлтийг нь харахуй 1538

Төгсгөлийн үг 1546

Энэхүү ном нь хоёр төрлийн тайлбар агуулдаг. Тоогоор тэмдэглэгдсэн ([1]гэх мэт) нь эх бичвэрийн тайлбар, харин үсгээр тэмдэглэгдсэн ([a]гэх мэт) нь орчуулгын тухай тайлбар юм.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

ХРИСТИЙН ЭХЭН ҮЕИЙН АЙЛДВАРУУД

ЧУУЛГАНУУДАД ХАНДСАН АРИУН СҮНСНИЙ ҮГ

(1991 ОНЫ 2-Р САРЫН 11—1991 ОНЫ 11-Р САРЫН 20)

ОРШИЛ

1991 оны 2-р сарын 11-нд Бурхан эхний айлдвараа айлдсан бөгөөд энэхүү айлдвар нь тухайн үеийн Ариун Сүнсний урсгалд амьдарч байсан хүн нэг бүрд хосгүй нөлөө үзүүлсэн юм. Энэхүү айлдвар нь “Бурханы оршин суудаг газар гарч ирлээ”, “Орчлон ертөнцийн Тэргүүн, эцсийн өдрүүдийн Христ—Тэр бол туяарах Нар” гэж дурдсан. Эдгээр гүн гүнзгий ач холбогдолтой үгийн хамтаар бүх хүн шинэ ертөнц рүү хүргэгджээ. Энэ айлдварыг уншсан бүх хүн Бурханы эхлүүлэх гэж буй агуу ажил буюу шинэ ажлын дохиог мэдэрсэн. Энэхүү үзэсгэлэнтэй, сонсголонтой, товч айлдвар нь бүх хүнийг Бурханы шинэ ажил, шинэ эрин үе рүү хүргэсэн ба энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажлын суурийг тавьж, ажлаа эхлүүлсэн юм. Бурханы энэ удаа хэлсэн айлдвар нь эрин үеүдийг холбодог гүүр гэж хэлж болно, энэ нь Нигүүлслийн эрин үеийн эхлэлээс хойш Бурхан хүн төрөлхтөнтэй ил тод ярьсан эхний удаа, Тэрээр хоёр мянган жилийн турш нуугдмал байсныхаа дараа ярьсан эхний удаа, түүнчлэн Хаанчлалын эрин үед Бурханы хэрэгжүүлэх гэж буй ажлын шийдвэрлэх чухал эхлэлийн цэг буюу оршил юм.

Бурхан анх удаа айлдвар айлдахдаа, гуравдагч хүний өнцгөөс магтаалын хэлбэрээр, яруу агаад ойлгомжтой хэлээр, мөн түүнчлэн хурдан, амархан ойлгож болох амийн хангалт хэлбэрээр айлдсан юм. Үүний хамтаар, Эзэн Есүсийн эргэн ирэхийг ихэд хүсэн хүлээхийн сацуу зөвхөн Түүний нигүүлслийг хэрхэн эдлэхээ л мэддэг цөөн тооны энэ бүлэг хүмүүсийг авч, Бурханы удирдлагын төлөвлөгөө дэх ажлын өөр үе шат руу чимээгүйхэн аваачсан билээ. Эдгээр нөхцөл байдал дор, Бурхан эцсийн дүнд ямар төрлийн ажил хийх гэж байгааг, эсвэл урагшлах замд юу хүлээж байгааг хүмүүс мэдээгүй бөгөөд төсөөлж бүр ч зүрхлээгүй. Түүнээс хойш, хүн төрөлхтнийг алхам алхмаар шинэ эрин үе рүү аваачихаар Бурхан нэмж айлдварууд айлдсаар л байв. Хачирхалтай нь, Бурханы айлдвар бүр агуулгаараа өөр бөгөөд түүнээс гадна өөр өөр магтаалын хэлбэр, илэрхийллийн аргыг ашигладаг. Өнгө аясын хувьд ижилхэн ч, агуулгын хувьд ялгаатай эдгээр айлдвар нь Бурханы анхаарал халамж, санаа зовнилын мэдрэмжээр байнга дүүрэн байдаг бөгөөд бараг тус бүр нь өөр өөр агуулгатай амийн хангалтыг, мөн түүнчлэн сануулга, ятгалга болон Бурханаас хүнд өгөх тайвшралын үгийг агуулдаг. Эдгээр айлдварт, дараахтай адил хэсэг удаа дараа гарч ирдэг: “Нэгэн жинхэнэ Бурхан махбод болсон бөгөөд Тэр бол бүх зүйлийг хянадаг орчлон ертөнцийн Тэргүүн”; “Ялгуусан Хаан алдар суут сэнтийдээ заларна”; “Тэр орчлон ертөнцийг Өөрийн гартаа атгадаг”; гэх мэтчилэн. Мэдээг эдгээр хэсгээр дамжуулдаг, эсвэл эдгээр хэсэг нь хүн төрөлхтөнд энэ мэдээг дамжуулдаг гэж хэлж болно: Бурхан хүний ертөнцөд хэдийнээ ирчихсэн, Бурхан илүү агуу ажлыг эхлүүлэх гэж байгаа ба Бурханы хаанчлал тодорхой бүлэг хүмүүс дунд хэдийнээ буучихсан, мөн Бурхан аль хэдийн алдар сууг олж авч, Өөрийн үй түмэн дайсныг ялсан. Бурханы айлдвар болгон хүн нэг бүрийн зүрх сэтгэлийг эзэмддэг. Бурхан илүү олон шинэ үг хэлэхийг

бүх хүн ихэд хүсэн хүлээдэг, учир нь Бурхан ярих бүрдээ хүний зүрх сэтгэлийн гүнийг догдлуулдаг ба түүнчлэн хүний бүх үйлдэл, сэтгэл хөдлөлийг удирдаж, дэмждэг, ингэснээр хүмүүс Бурханы үгэнд найдахын сацуу бүр бахдан биширч эхэлдэг… Тэд хуучны бичвэрүүдээс Бурханы эдгээр үгийн ямар ч үндэслэлийг олж чадаагүй, бас эдгээр айлдварыг айлдах Бурханы зорилгыг хаанаас ч олж илрүүлж чадаагүй учраас ийм маягаар үлэмж олон хүн өөрийн мэдэлгүй Библийг үндсэндээ мартаж, хуучинсаг номлолууд болон сүнслэг хүмүүсийн бичвэрийг бүр ч үл тоох болжээ. Ийм болохоор эдгээр айлдвар бол он цагийн эхлэлээс хойш харагдаж, сонсогдоогүй Бурханы дуу хоолой гэдгийг, мөн тэдгээр нь Бурханд итгэдэг ямар ч хүний хүрч чадахгүй зүйл гэдгийг, мөн өнгөрсөн эрин үеүдэд ямар ч сүнслэг хүний хэлсэн зүйлийг юм уу Бурханы урьдын айлдваруудыг даван гардаг гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй. Эдгээр айлдвар бүрээр зоригжин, хүмүүс санаандгүйгээр Ариун Сүнсний ажлын орчин руу, шинэ эрин үеийн тэргүүн зэргийн амьдрал руу орсон. Бурханы айлдвараар зоригжин, хүмүүс найдлагаар дүүрч, Бурханы үгээр биечлэн удирдуулахын жаргалыг амталдаг. Агшин зуурын энэ цаг хугацаа нь, хүн бүр өнө мөнхийн дурсамжтайгаар эргэн дурсах цаг байна гэдэгт Би итгэдэг, үнэндээ энэ хугацаанд хүний эдэлсэн зүйл нь Ариун Сүнсний ажлын орчноос илүүгүй байсан, эсвэл үүнийг эмийг бүрсэн сахрын чихэрлэг амт гэж хэлж болно. Яагаад гэвэл, энэ цэгээс эхлээд мөн л Бурханы үгийн удирдамж дор, Ариун Сүнсний ажлын орчинд хүмүүс өөрийн эрхгүй Бурханы үгийн өөр нэг шат руу хөтлөгдсөн, энэ нь Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажил болон айлдварын эхний алхам—үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт байсан юм.

Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтын өмнө айлдсан үг гол төлөв заавар, сургамж, зэмлэл, сахилгажуулалтын хэлбэртэй байсан бөгөөд зарим газарт Нигүүлслийн эрин үед хэрэглэдэг байсан нэрний хуучин хэлбэрийг ашигласан—хүн төрөлхтнийг Бурханд ойртоход илүү амархан болгохын тулд, эсвэл хүн төрөлхтөн Бурхантай харьцах харилцаагаа ойр дотно гэж бодог хэмээн Бурханыг дагадаг хүмүүст “Миний хөвгүүд” гэх нэрийг ашигласан. Ийм маягаар хүн төрөлхтний биеэ тоосон, ихэрхүү зан болон бусад завхарсан зан чанарт Бурхан ямар ч шүүлт явууллаа гэсэн хүн “Эцэг Бурхан”-ы айлдварын эсрэг дайсагнал өвөрлөлгүй, “хөвгүүн” гэх ялгамж чанараараа үүнтэй зохицож, хүлээн авч чаддаг байсны зэрэгцээ “Эцэг Бурхан”-ы Өөрийн “хөвгүүд”-эд өгсөн амлалтад хэзээ ч эргэлзэж байгаагүй. Энэ хугацаанд бүх хүн нялх хүүхдийнх шиг саад бэрхшээлгүй оршин тогтнолыг эдэлсэн нь Бурханы зорилгыг биелүүлж, ингэснээр “нас биед” хүрэхэд нь Бурхан тэдэн дээр шүүлт явуулж эхэлдэг байлаа. Энэ нь мөн Хаанчлалын эрин үед Бурханы албан ёсоор эхлүүлдэг, хүн төрөлхтнийг шүүх ажлын суурийг тавьсан юм. Энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажил гол төлөв бүхий л хүн төрөлхтнийг шүүж, байлдан дагуулах учраас хүн газар дээр хөлөө бат тавимагц Бурхан даруй Өөрийн ажлын горимд—хүнийг шүүж, гэсгээдэг ажилдаа орсон. Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтын өмнөх бүх айлдвар нь шилжилтийг даван туулахын төлөө хийгдсэн нь илэрхий

бөгөөд жинхэнэ зорилго нь харагдаж байгаагаасаа өөр байв. Бурхан Хаанчлалын эрин үеийн ажлаа аль болох түргэн албан ёсоор эхлүүлж чадна гэдэг оргилуун санаа зорилготой байлаа. Тэрээр сахраар бүрсэн эмээр тэжээх замаар хүн төрөлхтнийг ятган урагшлуулахыг огт хүсээгүй; харин ч шүүх суудлынхаа өмнө хүн бүрийн жинхэнэ төрхийг харахыг ихэд хүсэмжлэн, нигүүлслийг нь алдсаны дараах бүх хүний Өөрт нь хандах бодит хандлагыг харахыг бүр ч их хүссэн юм. Тэрээр үйл явц бус, зөвхөн үр дүн харахыг хүссэн. Гэвч хүний зүрх сэтгэл зөвхөн хүрэх газар, хэтийн ирээдүйгээ л анхаардаг байсан тул тэр үед Бурханы оргилуун санаа зорилгыг ойлгосон хэн ч үгүй байв. Бурханы шүүлт удаа дараа бүхий л хүн төрөлхтөнд чиглэсэнд гайхах зүйл үгүй. Хүмүүс Бурханы удирдамж дор хүний хэвийн амьдралаар амьдарч эхлэхэд л хүн төрөлхтөнд хандах Бурханы хандлага өөрчлөгдсөн юм.

1991 он бол ер бусын жил байлаа; энэ оныг “алтан он” гэж нэрлэцгээе. Бурхан Хаанчлалын эрин үеийн шинэ ажлыг эхлүүлж, бүхий л хүн төрөлхтөнд айлдвараа чиглүүлсэн. Үүнтэй зэрэгцэн, хүмүүс урьд хожид байгаагүй халуун дулааныг эдэлж, түүнчлэн хүнийг шүүх Бурханы урьд хожид байгаагүй шүүлтийг дагадаг өвдөлт шаналлыг мэдэрч туулсан юм. Хүн төрөлхтөн Бурханаар авхуулсан мэт, бас Бурханыг алдсан мэт өнөөг хүртэл мэдэгдээгүй, мэдрэгдээгүй жаргалыг амсаж, бас одоог хүртэл мэдэгдээгүй шүүлт, хаягдалтыг амссан. Эзэмшиж зовох, бас гачигдаж зовох—эдгээр мэдрэмжийг биеэр туулсан хүмүүс л мэддэг; эдгээрийг дүрслэх арга, чадварын аль аль нь хүнд байдаггүй. Энэ төрлийн шарх нь хүн бүрд биет бус туршлага, өв хөрөнгө болгон Бурханы хайрладаг зүйл юм. Энэ онд Бурханы айлдсан айлдварын агуулга үнэндээ хоёр томоохон бүлэгт хуваагддаг: Эхнийх нь хүмүүсийг сэнтийнхээ өмнө зочин болгон урихаар Бурхан хүний ертөнцөд бууж ирсэн; хоёр дахь нь цадталаа идэж уусан хүн төрөлхтнийг Бурхан үйлчлэл үзүүлэгчээр ажиллуулсан. Мэдээж хэрэг, хүмүүс эртнээс Бурханы бүх зүйлийг эдлэхийг Түүнд итгэх итгэлийнхээ объект болгож хэвшсэн учраас эхний хэсэг нь хүн төрөлхтний хамгийн нандин, чин сэтгэлийн хүсэл гэдгийг дурдах илүүц биз. Ийм учраас Бурханыг айлдвараа айлдаж эхэлмэгц хүмүүс бүгд хаанчлалд орж, Бурхан өөрсдөд нь янз бүрийн шагнал хайрлахыг хүлээхэд бэлэн байсан. Эдгээр нөхцөл байдалд хүмүүс зан чанараа өөрчилж, Бурханыг хангалуун байлгахаар чармайж, Бурханы хүсэлд хайхрамжтай хандах зэргээр зохих төлөөс ердөө төлөөгүй. Өнгөцхөн харахад, хүмүүс өөрсдийгөө зарлагадаж, Бурханы төлөө ажиллан, толгой өөд татах завгүй байгаа мэт санагддаг ч энэ хугацаанд тэд зүрх сэтгэлийнхээ гүн дэх нууцхан мухарт, ерөөл хүртэж, хаан болж хаанчлахын тулд дараа нь ямар алхам хийхээ тооцоолж байлаа. Хүний зүрх сэтгэл Бурханыг таашааж, үүний зэрэгцээ Бурханд тооцоололтой хандаж байсан гэж хэлэхэд болно. Энэ нөхцөлд байгаа хүмүүс Бурханы гүн гүнзгий зэвүүцэл, жигшилтэй тулгардаг; Өөрийг нь мэхэлж, ашиглаж байгаа ямар ч хүнийг Бурханы зан чанар тэвчдэггүй. Гэхдээ Бурханы мэргэн ухаанд ямар ч хүн хүршгүй. Энэ бүх зовлон шаналлыг туулж байх үедээ Тэр

айлдварынхаа эхний хэсгийг айлдсан юм. Бурхан хэчнээн их зовлон шаналал туулсан болохыг, энэ удаад хэчнээн их анхаарал, ухаан зарсан болохыг нэг ч хүн төсөөлж чадахгүй. Эдгээр айлдварын эхний хэсгийн зорилго нь албан тушаал, ашиг хонжоотой тулгарахдаа хүний үзүүлдэг бузар булай байдлын бүх төрлийн хэлбэрийг илчилж, мөн хүний шунал, жигшүүрт байдлыг илчлэх явдал юм. Хэдийгээр Бурхан ярихдаа Өөрийн үгийг элбэрэлт эхийн үнэнч, чин сэтгэлийн өнгөөр хэлдэг ч зүрхний гүн дэх уур хилэн нь дайснуудынх нь эсрэг чиглэсэн мэт, үд дундын нар шиг төөнөдөг. Ямар ч нөхцөлд Бурхан хүний хэвийн дүр төрхөөр дутмаг бүлэг хүмүүстэй ярих хүсэлгүй байдаг тул ярих бүрдээ зүрх сэтгэл дэх уур хилэнгээ дарж, үүний зэрэгцээ айлдвараа илэрхийлэхийн тулд биеэ барьж байдаг. Түүнчлэн хэвийн хүн чанаргүй, эрүүл ухаанаа гээсэн, туйлын их завхарсан, шуналд автсан, эцсээ хүртэл Бурханд дуулгаваргүй, тэрслүү ханддаг хүн төрөлхтөнтэй Тэрээр ярьж байна. Хүн төрөлхтний доройтлын гүн, хүн төрөлхтөнд хандах Бурханы үзэн ядалт, зэвүүцлийн хэмжээг амархан төсөөлж болно; хүн төрөлхтний хувьд төсөөлөхөд хэцүү байдаг зүйл нь Бурханд тэдний учруулсан шарх бөгөөд үүнийг үгээр илэрхийлэх аргагүй. Гэхдээ Бурханы зүрх сэтгэл хэрхэн шаналсныг хэн ч олж мэдэж чадаагүй, түүнчлэн хүн төрөлхтөн хэчнээн ухаангүй, засаршгүй байсныг хэн ч олж мэдээгүй—яг ийм байдалтай байхад—хүн бүр дор бүрнээ өчүүхэн ч ичгүүр, жаахан ч айж эмээх зүйлгүйгээр хүнд зориулан Түүний бэлдсэн бүх шагналыг Бурханы хөвгүүдийн хувиар хүлээн авах эрх дархтай гэж итгэн, хэн ч хоцрохыг хүсэлгүй, бүгд хожигдохоос гүнээ айж, бүр өөр хоорондоо тэмцэлдэх хэмжээнд хүрсэн. Тухайн үед Бурханы нүдэнд хүмүүс ямар байр суурь эзэлж байсныг одоо чи мэдэх хэрэгтэй. Ийм хүн төрөлхтөн яаж Бурханы шагналыг хүртэж чадах вэ? Гэвч хүний Бурханаас хүлээн авдаг зүйл цаг үргэлжид хамгийн нандин эрдэнэс байдаг бол, эсрэгээрээ Бурханы хүнээс хүлээн авдаг зүйл нь туйлын их шаналал байдаг. Бурхан, хүн хоёрын хоорондох харилцаа эхэлснээс хойш Бурханаас хүний үргэлж хүлээн авч, хариуд нь Бурханд үргэлж өгсөн зүйл нь энэ юм.

Бурхан сэтгэл түгшүүрт хэчнээн автсан ч, угтаа тултал завхарсан энэ хүн төрөлхтнийг хараад цэвэршиг гэж галт нууранд хаяхаас өөр сонголт Түүнд байгаагүй. Энэ бол Бурхан хүн төрөлхтнийг үйлчлэл үзүүлэгчдээр ажиллуулсан Бурханы айлдварын хоёр дахь хэсэг юм. Энэ хэсэгт Бурхан, “Бурханы үнэн бие”-ын байр суурийг хүний завхарсан уг чанарыг илчлэх өгөөш болгон ашиглаж, үүний зэрэгцээ хүмүүсээр сонгуулах гэж үйлчлэл үзүүлэгч, Бурханы ардууд, Бурханы хөвгүүд гэх ялгаатай ангиллуудыг[a] гарган, арга барил, хэмжээний аль алинд нь зөөлнөөс хатууд, цөөнөөс олонд шилжсэн. Мэдээж хэрэг яг Бурханы зөгнөсөнчлөн, Бурханд үйлчлэл үзүүлэгч болохыг хэн ч сонгоогүй, харин ч бүгд Бурханы үнэн бие болохоор эрмэлзсэн. Хэдийгээр энэ хугацаанд Бурханы хэлсэн үгийн хатуу ширүүн байдал нь хүн төрөлхтний хэзээ ч урьдчилан таамаглаагүй, бүр сонсож ч байгаагүй

[a] Эх бичвэрт “ялгаатай ангиллууд” гэх хэллэг байдаггүй.

зүйл байсан хэдий ч байр сууринд хэтэрхий анхаарч, үүн дээр нэмээд ерөөл хүртэхэд улайран автсан тэд Бурханы ярианы өнгө, Түүний ярианы арга маягийн талаар үзэл бий болгох ямар ч завгүй байсан бөгөөд харин ч өөрсдийн байр суурь болон ирээдүйд юу хүлээж байж болохыг оюун ухаандаа үргэлж дэнсэлсээр байв. Энэ маягаар Бурханы айлдвар хүнийг мэдээгүй байхад нь тэдэнд зориулж Бурханы зассан “төөрдөг байшинд” аваачсан. Аргагүйн эрхэнд ирээдүй болон өөрсдийн хувь тавилангийн өгөөшинд татагдсан хүн Бурханы үнэн бие болоход хангалтгүй гэдгээ мэдсэн боловч Түүний үйлчлэл үзүүлэгчээр ажиллахдаа дурамжхан байв. Эдгээр зөрчилдөөнтэй сэтгэхүйн хооронд тээнэгэлзсэн тэд өөрсдийн мэдэлгүйгээр, хүмүүст Бурханы оноосон урьд хожид байгаагүй шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрчээ. Угтаа шүүлт, цэвэршүүлэлтийн энэ хэлбэр нь хүн төрөлхтний яавч хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй зүйл байв. Хэдий тийм ч, завхарсан энэ хүн төрөлхтнөөс номхон хүлцэнгүй байдлыг шаардах мэргэн ухаан, хүч чадал зөвхөн Бурханд л байдаг учраас тэд хүссэн ч, хүсээгүй ч эцэст нь бүгд бууж өгчээ. Хүнд өөр сонголт байсангүй. Бурхан л эцсийн шийдвэрийг гаргадаг бөгөөд зөвхөн Бурхан л, хүнд үнэн ба амийг хайрлаж, түүнд замыг заахын тулд ийм арга барил ашиглаж чаддаг. Энэ арга барил нь хүн дээрх Бурханы ажлын зайлшгүй байдал бөгөөд мөн эргэлзээ, маргаангүйгээр хүний салшгүй хэрэгцээ юм. Энэ баримтыг хүнд дамжуулахдаа Бурхан ийм аргаарүг хэлж, ажилладаг: Бурхан Өөрийн хайр, өршөөлөөс болж, мөн Өөрийн удирдлагын төлөө хүнийг авардаг; хүн төрөлхтөн Бурханы биечлэн ярихаас өөр аргагүй цэгт хүртлээ доройтсон учраас Бурханы авралыг хүлээн авдаг. Хүн Бурханы авралыг хүлээн авах үе нь хамгийн агуу нигүүлсэл, мөн онцгой ивээл юм; өөрөөр хэлбэл, Бурхан айлдвараа биечлэн айлдаагүй бол хүн төрөлхтний хувь заяа эцэс болох байлаа. Бурхан хүн төрөлхтөнд зэвүүцэхийн зэрэгцээ хүний авралын төлөө ямар ч төлөөс төлөхөд бас л бэлэн, тэгэх хүсэлтэй байдаг. Харин хүн Бурханыг гэх хайрынхаа тухай, мөн Бурханд яаж бүхнийг зориулдгаа улиг болтол яригаа Бурханы эсрэг тэрсэлж, Бурханаас бүх төрлийн нигүүлслийг нэхэн авангаа бүр Бурханыг шархлуулж, Түүний зүрх сэтгэлд үгээр илэрхийлэхийн аргагүй өвдөлт шаналал учруулдаг. Бурхан хүн хоёрын хооронд амь биеэ хайрладаггүй сэтгэл ба аминч сэтгэлийн ийм тод томруун ялгаа бий!

Бурхан ажиллаж, ярихдаа тодорхой нэг арга барилыг дагахаар хязгаарлагдалгүй, үр дүнд хүрэхийг зорилгоо болгодог. Ийм учраас, айлдваруудынхаа энэ хэсэгт Бурхан Өөрийн ялгамж чанарыг тодорхой дэлгэлгүй, зөвхөн “эцсийн өдрүүдийн Христ”, “орчлон ертөнцийн Тэргүүн” зэрэг цөөн хэдэн нэр томьёог л ил болгохоо тодорхой хэлсэн юм. Ялангуяа эрт үед хүн “Христ”, “бие махбодтой болох” зэрэг ойлголтыг ер мэддэггүй байсан тул Бурхан айлдвараа илэрхийлэхийн тулд Өөрийгөө “тусгай үүрэг”-тэй хүн болгон дорд болгох ёстой болсон нь Христийн үйлчлэл, эсвэл Бурханы талаарх хүмүүсийн мэдлэгийн аль алинд огт нөлөөлдөггүй. Тухайн үеийн хүмүүс зөвхөн ийм хэлбэрийн нэрийг л хүлээн авч чадах байсан

учраас энэ бол Бурханы уйгагүй анхаарал халамж, бодол санаа юм. Бурхан ямар ч хэлбэрийн нэр хэрэглэлээ гэсэн, Түүний ажлын үр дүнд нөлөөлдөггүй, учир нь Бурхан хийдэг бүхнээрээ хүнд өөрчлөгдөж, Бурханы авралыг олж авах боломж олгохыг зорьдог. Бурхан юу ч хийлээ гэсэн хүний хэрэгцээг үргэлж бодолцдог. Энэ бол Бурханы ажиллаж, үг хэлдгийн цаад санаа зорилго юм. Хэдийгээр Бурхан хүмүүсийн бүх талыг бодолцохдоо бүрэн анхааралтай байж, хийдэг бүхэндээ үнэхээр бүрэн ухаалаг байдаг боловч Би ингэж хэлж чадна: Хэрэв Бурхан Өөртөө гэрчлэл хийгээгүй бол бүтээгдсэн хүн төрөлхтний дунд Бурханыг Өөрийг нь таньж, эсвэл Бурханд Өөрт нь гэрчлэл хийхээр босох чадвартай хэн ч байхгүй байх байлаа. Хэрвээ Бурхан “тусгай үүрэгтэй хүн”-ийг ажилдаа нэр хэлбэрээр ашигласаар байсан бол Бурханыг Бурхан гэж харж чадах ганц ч хүн байхгүй байх сан—энэ бол хүн төрөлхтний уй гашуу юм. Өөрөөр хэлбэл, бүтээгдсэн хүн төрөлхтний дунд Бурханыг мэдэж чадах нэг ч хүн үгүй, Бурханыг хайрлаж, Бурханыг хайхарч, Бурханд ойртож чадах хүн бүр ч байхгүй. Хүний итгэл гагцхүү ерөөл хүртэхийн төлөө л байдаг. Тусгай үүрэгтэй хүн гэх Бурханы ялгамж чанар хүн нэг бүрд битүүхэн сануулсан: Бурханыг бүтээгдсэн хүн төрөлхтний нэг гэж үзэх нь хүн төрөлхтөнд амархан байдаг; Бурхан ил тод илэрч, ажиллахдаа бас л хүнд гологдож, тэр ч бүү хэл мартагддаг нь хүн төрөлхтний Бурханд учруулдаг хамгийн их өвдөлт шаналал, басамжлал юм. Бурхан хүн төрөлхтнийг аврахын тулд хамгийн их басамжлалыг туулдаг; бүхнийг өгдөг Түүний зорилго нь хүн төрөлхтнийг аврахын төлөө, хүн төрөлхтнөөр хүлээн зөвшөөрөгдөхийн төлөө байдаг. Энэ бүхний төлөө Бурханы төлсөн төлөөс бол мөс чанартай хүн бүрийн ойлгож чаддаг байх ёстой зүйл юм. Хүн төрөлхтөн Бурханы айлдвар, ажлыг олж авч, Бурханы авралыг хүртсэн. Үүний зэрэгцээ ингэж асууя гэж хэнд ч бодогдоогүй: Бурхан хүн төрөлхтнөөс яг юу олж авсан юм бэ? Бурханы айлдвар болгоноос хүмүүс үнэнийг олж авч, амжилттайгаар өөрчлөгдөж, амьдралд зүг чигээ олсон; гэтэл Бурханы олж авсан зүйл гэвэл Бурханд өртэйгээ илэрхийлэхдээ хүмүүсийн ашигладаг үг, бас магтаалын цөөн сулхан шивнээнээс хэтрэхгүй. Бурханы хүнээс шаарддаг нөхөн төлбөр энэ биш л байлтай?

Бурхан олон айлдвар илэрхийлсэн боловч дийлэнх хүмүүсийн Бурханы тухай мэдлэг, ойлголт нь зөвхөн Бурханы эхэн үеийн айлдварын үе шатанд үлдэж, тэндээс урагшлаагүй хэвээр байна—энэ бол үнэхээр хөндүүр сэдэв юм. “Христийн эхэн үеийн айлдваруудын” энэ хэсэг нь ердөө л хүний зүрх сэтгэлийг нээх түлхүүр төдий; энд саатах нь Бурханы санаа зорилгыг биелүүлэхээс хамаагүй хол хоцорно гэсэн үг. Бурхан айлдварынхаа энэ хэсгийг айлдсаны зорилго нь зөвхөн хүмүүсийг Нигүүлслийн эрин үеэс Хаанчлалын эрин үе рүү аваачих явдал юм; хүн төрөлхтөн Өөрийнх нь айлдварын энэ хэсэгт зогсонги байдалтай үлдэж, эсвэл бүр айлдварынх нь энэ хэсгийг зааварчилгаа болгоосой гэж Тэр яавч хүсдэггүй, эс бөгөөс Бурханы хожмын айлдварууд хэрэгцээ ч үгүй, утга учир ч үгүй байх байлаа. Хэрвээ айлдварынх нь энэ хэсгээс хүний олж авахыг Бурханы шаарддаг зүйлд орж

хараахан чадахгүй хүн байвал тухайн хүний оролт мэдэгдэхгүй үлддэг. Бурханы айлдварын энэ хэсэг нь Хаанчлалын эрин үед Бурханы хүнд тавьдаг хамгийн үндсэн шаардлагыг бүрдүүлдэг, зөвхөн энэ аргаар л хүн төрөлхтөн зөв замд орно. Хэрэв чи юу ч ойлгодоггүй хүн бол энэ хэсэг дэх үгийг уншсанаар эхэлсэн чинь дээр!

1-Р БҮЛЭГ

Сионы магтаалын өдөр ирж, Бурханы оршин суудаг газар гарч ирлээ. Бүх ард түмний магтдаг суу алдарт ариун нэр түгж байна. Ай, Төгс Хүчит Бурхан минь! Орчлон ертөнцийн Тэргүүн, эцсийн өдрүүдийн Христ. Тэр бол бүхий л орчлон ертөнцийн дээр сүр жавхлантай, эрхэмсгээр сүндэрлэдэг Сион уулнаа мандсан гэрэлт Нар билээ…

Төгс Хүчит Бурхан минь! Бид Таныг баяр хөөртэйгөөр дууддаг; бид бүжиглэж, дуулдаг. Та бол үнэхээр бидний Золин Аврагч, орчлон ертөнцийн агуу Хаан! Та бүлэг ялагчийг бий болгож, Бурханы удирдлагын төлөвлөгөөг биелүүлсэн. Бүх ард түмэн энэ уул руу цуварна. Бүх ард түмэн сэнтийн өмнө сөгдөн мөргөнө! Та бол цорын ганц жинхэнэ Бурхан бөгөөд алдар, хүндлэл хүртэх эрхтэй билээ. Бүх алдар, магтаал, эрх мэдэл сэнтийд байх болтугай! Амийн булаг сэнтийгээс урсан гарч, Бурханы үй олон ардыг усалж, тэжээдэг. Амь өдөр бүр өөрчлөгддөг; шинэ гэрэл, илчлэлүүд биднийг дагаж, Бурханы тухай шинэ гүнзгий ойлголтыг байнга өгдөг. Бид туршлагын дунд Бурханы талаар бүрэн итгэлтэй болдог. Түүний үг байнга ил болж, зөв хүмүүс дотор илэрдэг. Бид үнэндээ маш их ерөөгдсөн! Өдөр бүр Бурхантай нүүр тулан уулзаж, бүх зүйл дээр Бурхантай ярилцаж, бүх зүйлийг удирдах дээд эрхийг Бурханд өгдөг. Бид Бурханы үгийг сайтар тунгааж, зүрх сэтгэл маань Бурханы дотор тайван болдог, ийм маягаар бид Бурханы өмнө очиж, тэндээс Түүний гэрлийг хүлээн авдаг. Бид өдөр бүр амьдрал, үйлдэл, үг яриа, бодол, санаа бүртээ Бурханы үг дотор амьдарч, цаг ямагт ялган таньж чаддаг. Бурханы үг чадварлагаар залж чиглүүлдэг; санамсаргүй байхад л дотор нуугдсан зүйлс ээлж дараалан ил гарна. Бурхантай нөхөрлөх нөхөрлөлд алгуурлахыг тэвчдэггүй юм; Бодол, санаануудыг маань Бурхан ил болгодог. Хором бүрд бид өөрсдийнхөө шүүлтэд ордог газар болох Христийн суудлын өмнө амьдарч байна. Бидний бие доторх хэсэг бүрийг Сатан эзэмдсэн хэвээр байдаг. Өнөөдөр, Бурханы дээд эрхийг сэргээхийн тулд Түүний сүмийг цэвэрлэх ёстой. Бурханаар бүрэн эзэмдүүлэхийн тулд бид үхэх сэхэхээ үзэн тэмцэх ёстой. Хуучны бид цовдлогдсон цагт л дахин амилсан Христийн амь мандан бадрах болно.

Одоо, Ариун Сүнс бидний сэргэлтийн төлөө тулаан хийхийн тулд булан тохой бүр лүү маань довтлон дайрдаг! Бид өөрсдийгөө үгүйсгэхэд бэлэн байж, Бурхантай хамтран ажиллахыг хүсэж байгаа цагт Бурхан биднийг дотроос маань үргэлж гэрэлтүүлэн ариусгаж, Сатаны эзэмшсэнийг шинээр сэргээх нь гарцаагүй, ингэснээр

Бурхан биднийг аль болох хурдан бүрэн төгс болгож болох юм. Цагаа бүү үр, хором бүрд Бурханы үг дотор амьдар. Ариун хүмүүсийн хамт өсөн хөгжиж, хаанчлалд хүргэгдэж, Бурхантай хамт алдар луу ор.

2-Р БҮЛЭГ

Филадельфийн чуулган хэлбэрээ олсон нь бүхэлдээ Бурханы нигүүлсэл, өршөөлийн ач юм. Үй олон ариун хүмүүсийн зүрх сэтгэлд Бурханыг гэх хайр бий болж, тэд сүнслэг замаараа гуйвж дайвалгүй алхдаг. Цор ганц жинхэнэ Бурхан махбод болсон бөгөөд Тэр бол бүх зүйлийг захирдаг орчлон ертөнцийн Тэргүүн гэсэн итгэлээ тэд бат баримталдаг: Үүнийг Ариун Сүнс баталгаажуулсан бөгөөд энэ нь уулс мэт хөдөлшгүй үнэн юм! Мөн энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй!

Өө, Төгс Хүчит Бурхан минь! Өнөөдөр Та бидний сүнслэг нүдийг нээж, сохор нь харж, доголон нь алхаж, уяман өвчтөн нь эдгэх боломж олгосон. Та тэнгэрийн цонхыг нээж, бидэнд сүнсний ертөнцийн нууцуудыг ойлгох боломжийг олгосон. Бидэнд Таны ариун үгс шингэж, Сатаны завхруулсан хүн чанараас биднийг аварсан—энэ бол Таны хэмжээлшгүй агуу ажил, Таны хэмжээлшгүй их өршөөл билээ. Бид бол Таныг гэрчлэгч!

Та удаан хугацаанд даруухнаар, чимээгүйхнээр нуугдмал байж ирсэн. Та ахин амилалт, цовдлолын зовлон, хүний амьдралын баяр хөөр, уй гашууг, хавчлага, бэрхшээлийг үзсэн; Та хүний ертөнцийн зовлон шаналлыг туулж, амссан, бас Та эрин үед хаягдсан. Бие махбодтой болсон Бурхан бол Бурхан Өөрөө юм. Бурханы хүслийн төлөө Та биднийг овоолсон өтөг бууцнаас аварч, баруун гараараа биднийг өргөн, нигүүлслээ бидэнд үнэгүй өгсөн. Зовлон шаналлыг үл хайхран, Өөрийн амийг бидэнд оруулсан; цус, хөлс, нулимсаараа Таны төлсөн төлөөс ариун хүмүүс дээр биеллээ олсон. Бид бол Таны уйгагүй хүч чармайлтын үр дүн;[a] бид бол Таны төлсөн төлөөс.

Өө, Төгс Хүчит Бурхан минь! Таны хайр болон өршөөл, Таны зөвт байдал болон сүр жавхлан, Таны ариун агаад даруу байдлаас үүдэн бүх хүн Таны өмнө сөгдөж, үүрд мөнхөд Таныг шүтэн мөргөнө.

Өнөөдөр Та бүх чуулганыг—Филадельфийн чуулганыг—бүрэн төгс болгож, өөрийн 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөгөө хэрэгжүүлсэн. Ариун хүмүүс сүнсээрээ холбогдон, хайраар дагалдаж, булгийн эхтэй нэгдэн Таны өмнө даруухнаар захирагдаж чадна. Амийн амьд ус зогсолтгүй урсаж, чуулган дахь бүхий л шавар шавхай, бохир усыг угааж, цэвэрлэн, Таны сүмийг дахин нэгэнтээ ариусгаж байна. Бид бодитой жинхэнэ Бурханыг мэдэж авч, Түүний үгсийн дагуу алхаж, өөрсдийн үүрэг, хариуцлагыг танин мэдэж, чуулганы төлөө өөрсдийгөө

[a] Эх бичвэрт “үр дүн” гэх хэллэг байдаггүй.

зарлагадахын тулд чадах бүхнээ хийсэн. Таны хүслийг саатуулахгүйн тулд бид хором бүрд Таны өмнө тайван байж, Ариун Сүнсний ажлыг анхаарах ёстой. Ариун хүмүүс харилцан бие биеэ хайрладаг бөгөөд заримынх нь давуу тал бусдынхаа алдаа дутагдлыг нөхнө. Тэд цаг ямагт сүнс дотор алхаж, Ариун Сүнсээр гэгээрүүлэгдэж, гэрэлтүүлэгдэж чаддаг. Тэд үнэнийг ойлгосон даруйдаа хэрэгжүүлдэг. Тэд шинэ гэрэлтэй хөл нийлүүлж, Бурханы мөрийг дагадаг.

Бурхантай идэвхтэй хамтран ажилла; Түүнд хяналтыг өгнө гэдэг нь Түүнтэй хамт алхаж буй явдал юм. Бидний бүх санаа, үзэл, бодол, энэ ертөнцийн ээдрээ агаарт утаа мэт замхардаг. Бид Бурханыг сүнсэндээ хаанчлуулж, Түүнтэй хамт алхаж, тэгсэнээрээ ангид оршиж, дэлхий ертөнцийг ялан дийлэх бөгөөд бидний сүнс чөлөөтэй нисэж, чөлөөлөлтөд хүрдэг: Энэ нь Төгс Хүчит Бурхан Хаан болох үеийн үр дүн юм. Бид бүжиглэж, магтан дуулж, магтаалаа өргөж, шинэ дуугаа өргөхгүй байж яаж чадах билээ?

Бурханыг магтах үнэхээр олон зам бий: Түүний нэрийг дуудах, Түүнд ойртох, Түүнийг бодох, залбиран-унших, нөхөрлөх, бодож бясалгах, тунгаах, залбирал болон магтаалын дуу. Эдгээр магтаалын төрөлд таашаал ч бий, тослолт ч бий; магтаалд хүч байдаг, бас ачаа ч байдаг. Магтаалд итгэл байдаг, шинэ ойлголт ч байдаг.

Бурхантай идэвхтэй хамтран ажилла, уялдаатай үйлчилж, нэгд, Төгс Хүчит Бурханы санаа зорилгыг биелүүл, ариун сүнслэг бие болохоор яаравчил, Сатаныг гишгэл, Сатаны хувь заяаг төгсгөл болго. Филадельфийн чуулган Бурханы өмнө өргөгдсөн бөгөөд Бурханы алдраар тунхаглагддаг.

3-Р БҮЛЭГ

Ялгуусан Хаан алдар суут сэнтийдээ заларна. Тэрээр золин авралыг гүйцэлдүүлж, Өөрийн бүх ардыг алдар суутайгаар гарч ирэхэд удирдан хөтөлсөн юм. Тэрээр орчлон ертөнцийг гартаа атгаж, ариун мэргэн ухаан болон сүр хүчээрээ Сионыг барьж, бэхжүүлсэн. Сүр жавхлангаараа Тэр нүгэлт ертөнцийг шүүдэг; Тэрээр бүх үндэстэн, бүх ард түмэн, газар дэлхий, тэнгис далай хийгээд тэдгээрт буй бүхий л амьд зүйлийг, мөн түүнчлэн садар самууны дарсанд согтогсдыг шүүдэг. Бурхан тэднийг гарцаагүй шүүж, тэдэнд уурсах нь дамжиггүй бөгөөд үүгээр эгшин зуур, сааталгүйгээр шүүлтээ явуулдаг Бурханы сүр жавхлан илчлэгдэнэ. Бурханы уур хилэнгийн гал тэдний жигшүүрт гэмт хэргийг шатааж, хэзээ мөдгүй тэдэнд гай гамшиг тохиолдоно; тэд зугтан зайлах ямар ч арга зам мэдэхгүй, нуугдах ямар ч газаргүй байх ба уйлж, шүдээ хавирна, тэгээд өөрсдөдөө сүйрэл авчирна.

Бурханы ялгуусан хайрт хөвгүүд Сионд үлдэх нь эргэлзээгүй бөгөөд тэндээс хэзээ ч явахгүй. Асар олон ард түмэн Түүний дуу хоолойг анхааран сонсож, үйлдлийг нь нухацтай анхаарах бөгөөд тэдний магтаалын дуу хэзээ ч зогсохгүй. Цорын ганц жинхэнэ Бурхан гарч ирлээ! Бид Түүнд сүнсээрээ итгэлтэй болох

бөгөөд Түүнийг ойрхон дагана; хамаг чадлаараа урагш давшиж, дахиж эргэлзэхээ болино. Дэлхийн төгсгөл бидний өмнө дэлгэгдэж байна; чуулганы зөв зохистой амьдрал болон биднийг хүрээлэн буй хүмүүс, юмс, хэрэг явдал одоо ч гэсэн бидний сургуулилалтыг эрчимжүүлж байна. Дэлхий ертөнцийг ихэд хайрладаг зүрх сэтгэлээ буцаан авахаар яаравчилцгаая! Тун их муудсан хараагаа буцаан сайжруулахаар яаравчилцгаая! Хэрээс хэтрэхгүйн тулд хөлөө хорьё. Амаа хамхицгаая, ингэснээр бид Бурханы үгээр амьдарч, өөрсдийн ашиг, алдагдлын төлөө арцалдахаа больж магадгүй юм. Аяа, дэлхий ертөнц болон эд хөрөнгөд шунан дурладгаа зогсоо! Аяа, нөхөр, охид, хөвгүүдтэйгээ зууралдан хоргодохоос өөрсдийгөө чөлөөл! Аяа, өөрсдийн үзэл санаа, атраг сэжгээс татгалз! Аяа, сэрцгээ; цаг бага байна! Сүнсээрээ дээш хар, дээш хар, Бурханаар удирдуул. Юу тохиолдовч Лотын эхнэр шиг болж болохгүй. Хөсөр хаягдана гэдэг хэчнээн өрөвдөлтэй вэ! Ямар өрөвдөлтэй гээч! Аяа, сэрцгээ!

4-Р БҮЛЭГ

Бид үргэлж харж, хүлээж, сүнсээрээ тайван байж, ариун зүрх сэтгэлээр эрж хайна. Юу ч тохиолдсон бай, бид сохроор нөхөрлөх ёсгүй. Бид зөвхөн Бурханы өмнө тайван байж, Түүнтэй байнга нөхөрлөж байх хэрэгтэй, тэгвэл Түүний санаа зорилго бидэнд гарцаагүй илчлэгдэх болно. Сүнсэн дотор бид цаг ямагт ялгаж салгахад бэлэн байж, гярхай, няцашгүй сүнстэй байх ёстой. Бурханы өмнө бид хатсан сүнсийг маань тэжээж, дүүргэдэг амийн уснаас хүртэх ёстой. Бид өөрийгөө зөвтгөдөг, биеэ тоосон, ихэрхүү, бардам сатанлаг зан чанараа цэвэрлэхэд цаг үргэлжид бэлэн байх ёстой. Бурханы үгийг хүлээн авахын тулд зүрх сэтгэлээ нээж, Түүний үгэнд үндэслэн үйлдэл хийх ёстой. Бид Түүний үгийг туулан, үүнд итгэлтэй байж, Түүний үгийг ойлгож, Түүний үгийг өөрсдийн амь болгох ёстой. Энэ бол бидэнд тэнгэрээс илгээсэн дуудлага! Бид Бурханы үгээр амьдрах үедээ л ялгуусан байж чадна!

Одоо үзэл маань хэт ноцтой болж, бид хий хоосон ярьж, хөнгөн хуумгай үйлдэн, Сүнсийг дагаж чаддаггүй. Өнөөдөр бол урьдынх шиг биш. Ариун Сүнсний ажил агуу хурдаар урагшилдаг. Бид Бурханы үгийг нэг бүрчлэн туулах ёстой; санаа, бодол бүрийг, хөдөлгөөн, хариу үйлдэл бүрийг бид зүрх сэтгэлдээ тодорхой ялган салгаж чаддаг байх ёстой. Хүний нүүрэн дээр, эсвэл ар хударгаар нь хийсэн юу ч бай Христийн суудлын өмнөх шүүлтээс мултарч чадахгүй. Ариун Сүнс биднийг илүү гүн гүнзгий туршлагын ертөнц рүү хөтөлж байгаа ба тэнд бид Төгс Хүчитийн талаар улам итгэлтэй болно.

Орчлон ертөнцийн Бурхан бидний сүнслэг нүдийг нээж, сүнсэн дэх нууц бидэнд тасралтгүй илчлэгдсээр байна. Ариун зүрх сэтгэлээр эрж хайгтун! Төлөөс төлөхөд бэлэн бай, эв нэгдэлтэйгээр урагшил, өөрийгөө үгүйсгэхэд бэлэн бай, шунахай

байхаа боль, Ариун Сүнсийг дагаж, Бурханы үгийг эдэл, тэгвэл бүх орчлон ертөнцийн цоо шинэ хүн гарч ирэх болно. Сатаны төгсгөл ирж, Бурханы хүсэл гүйцэлдэж, дэлхийн бүх улс үндэстэн Христийн хаанчлал болж, Христ газар дээр үүрд мөнх хаанчлах хором ойрхон байна!

5-Р БҮЛЭГ

Уулс, гол мөрөн өөрчлөгдөж, ус голдрилоороо урсдаг ба хүний амь газар, тэнгэр шиг удаан оршдоггүй. Зөвхөн Төгс Хүчит Бурхан л үеийн үед үүрд амьдардаг мөнхийн бөгөөд амилсан амь билээ! Бүх зүйл, бүх үйл явдал Түүний гарт байдаг ба Сатан Түүний хөл дор байдаг.

Бурханы урьдчилан тогтоосон сонголтоор өнөөдөр Тэр биднийг Сатаны атганаас аварч байна. Тэр бол үнэхээр бидний Золин Аврагч юм. Биднийг Бурханы амьтай холбохоор зорьж, Христийн мөнхийн, амилсан амийг үнэндээ бидний дотор урлан хийсээр ирсэн нь бид үнэндээ Түүнтэй нүүр учран, Түүнийг идэж, Түүнийг ууж, Түүнийг эдэлж чадаж болох юм. Энэ бол Бурхан зүрхнийхээ цусаар төлж, амь бие үл хайрлан хийсэн тахил билээ.

Улирлууд салхи, жавар дамжин өнгөрч, амьдралын асар их шаналал, хавчлага, зовлон, дэлхий ертөнцийн асар их үгүйсгэл, гүжирдлэг, засгийн газрын асар их гүтгэлэгтэй нүүр тулан ирж, одовч Бурханы итгэл ч, Түүний шийдэмгий зан ч огт багасдаггүй. Бурханы хүсэл, Бурханы удирдлага болон төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн төлөө чин сэтгэлээсээ биеэ зориулсан Тэр Өөрийн амийг зөнд нь орхидог. Өөрийн бүх үй олон ардын төлөө Тэр биеэ үл хайрлаж, тэднийг болгоомжтой тэжээж, усалдаг. Бид хэчнээн мунхаг, хэчнээн хэцүү байдаг маань хамаагүй, бид зөвхөн Түүний өмнө дуулгавартай байх ёстой ба Христийн амилсан амь бидний хуучин уг чанарыг өөрчилнө… Энэ ууган хөвгүүдийнхээ төлөө Тэр цуцалтгүй хөдөлмөрлөж, нойр хоолоо умартдаг. Хэчнээн олон өдөр, шөнө, хэчнээн шатам халуун, тэсгим хүйтэнд Тэр Сионоос бүх чин сэтгэлээсээ харуулддаг гээч.

Дэлхий ертөнц, гэр орон, ажил болон бүхнийг баяртайгаар, сайн дураараа умартсан, хорвоогийн зугаа цэнгэл Түүнд огт хамаагүй… Түүний амнаас гарсан үг биднийг цохиж, зүрх сэтгэлийн маань гүнд нуугдсан зүйлсийг ил болгодог. Бид үнэмшихгүй байж хэрхэн чадах юм бэ? Түүний амнаас гарсан өгүүлбэр бүр бидний дотор хэдийд ч биелж болно. Түүний нүдэн дээр, эсвэл Түүний нүднээс далд бид юу хийвч Түүнд мэддэггүй, хардаггүй юу ч үгүй, ойлгодоггүй юм Түүнд үгүй. Үнэн хэрэгтээ бидний төлөвлөгөө, зохицуулалтыг эс харгалзан бүгд Түүний өмнө ил гарах болно.

Түүний өмнө суугаад сэтгэлдээ баяр хөөр мэдрэн амгалан тайван байх атал үргэлж хоосон санагдаж, Бурханд үнэхээр өртэйгээ мэдэрдэг: Энэ бол төсөөлшгүй, хүрэх боломжгүй гайхамшиг билээ. Төгс Хүчит Бурхан бол ганц жинхэнэ Бурхан гэдгийг батлахад Ариун Сүнс хангалттай! Энэ бол бараггүй нотолгоо! Энэ бүлгийн

бид өгүүлшгүй их ерөөгдсөн! Бурханы нигүүлсэл болон өршөөл байгаагүй бол бид мөхөж, Сатаныг л дагах байсан. Төгс Хүчит Бурхан л биднийг аварч чадна!

Ай! Бодитой Бурхан, Төгс Хүчит Бурхан минь! Бидний сүнслэг нүдийг нээж, сүнсний ертөнцийн нууцуудыг олж харах боломжийг Та олгосон билээ. Хаанчлалын төлөв хязгааргүй. Хүлээхдээ сонор сэрэмжтэй байя. Тэр өдөр тийм ч хол байж болохгүй.

Дайны гал бургиж, үхэр бууны утаа баагьж, цаг агаар дулаарч, уур амьсгал өөрчлөгдөж, тахал тархах бөгөөд хүмүүс амьд үлдэх горьдлогогүй, үхэхээс л аргагүй болно.

Ай! Бодитой Бурхан, Төгс Хүчит Бурхан минь! Та бол бидний дархан цамхаг. Та бол бидний хоргодох газар. Бид Таны жигүүр дор бөөгнөх ба гай гамшиг бидэнд хүрч чадахгүй. Энэ нь Таны бурханлаг хамгаалалт, халамж билээ.

Бид бүгд дуугаа чангалан дуулна; бид магтан дуулж, бидний магтаалын чимээ Сион даяар цуурайтна! Бодитой Бурхан, Төгс Хүчит Бурхан бидэнд алдар суут хүрэх газрыг бэлдчихсэн. Сэрэмжтэй бай, ай, соргог бай! Хараахан хожимдоогүй байна.

6-Р БҮЛЭГ

Төгс Хүчит Бурхан, бүх зүйлийн Тэргүүн Өөрийн сэнтийгээс хааны эрх мэдлээ захиран зарцуулдаг. Тэрээр орчлон ертөнц болон бүх зүйлийг захирдаг бөгөөд газар даяар бид бүгдийг залж чиглүүлж байна. Бид хором мөч бүрд Түүнтэй ойр байж, нэг ч хормыг алдалгүйгээр, бидний цаг үргэлж сурах хичээлийг тээн Түүний өмнө тайвнаар очих болно. Хүрээлэн буй орчноос авхуулаад хүмүүс, юмс, эд зүйлс хүртэл бүгд Түүний сэнтийн зөвшөөрөлтэй оршин байдаг. Ямар ч тохиолдолд зүрх сэтгэлдээ гомдол бүү төрүүл, эс тэгвээс Бурхан чамд нигүүлслээ хайрлахгүй. Өвчин зовлон тохиолдвоос энэ нь Бурханы хайр бөгөөд Түүний сайн санаа үүний ард байгаа нь мэдээж. Бие чинь багахан зовлон туулж болох ч Сатанаас ирэх санааг бүү өөгшүүл. Өвчин дундаа Бурханыг магтаж, магтаал дундаа Бурханыг таашаа. Өвчинтэй нүүр туулахдаа бүү хулчий, үргэлжлүүлэн эрж хайж, хэзээ ч бүү бууж өг, тэгвэл Бурхан Өөрийн гэрлийг чам дээр тусгах болно. Иовын итгэл ямар байсан бэ? Төгс Хүчит Бурхан бол хэмжээлшгүй чадалтай эмч билээ! Өвчинд оршино гэдэг нь өвдөхийн нэр, сүнсэнд оршино гэдэг эрүүл байхын нэр. Тиймээс ганц ч болов амьсгал үлдсэн байвал Бурхан чамайг үхүүлэхгүй.

Дахин амилсан Христийн амь бидний дотор бий. Бурханы өмнө бидний итгэл маргаангүй дутмаг. Бурхан бидний дотор жинхэнэ итгэл хайрлах болтугай. Бурханы үг үнэхээр сайхан! Бурханы үг бол хүчтэй эм юм! Энэ нь диаволууд болон Сатаныг шившиг болгодог! Бурханы үгийг ухаарах нь бидэнд дэмжлэг болдог. Түүний үг зүрх сэтгэлийг маань хурдан авардаг! Бурханы үг бүхнийг сарниулж, бүгдийг амар тайван болгодог. Итгэл бол дан гуалин гүүртэй адил, өрөвдөлтэйгээр

амьтайгаа зууралддаг хүмүүс гатлахад хэцүү, харин өөрсдийгөө золиослоход бэлэн хүмүүс хөл алдалгүй, санаа амар гаталж чаддаг. Хүн хулчгар, аймхай бодол тээх нь Сатан түүнийг мэхэлж, Бурхан руу орох вий гэж айсандаа хуурч буй хэрэг юм. Сатан өөрийн бодлыг бидэнд илгээхийн тулд боломжит бүх арга замыг сэдэж байгаа. Бид Бурханаас гэрлээрээ биднийг гэрэлтүүлэхийг гуйн хором мөч бүрд залбирч, дотроосоо Сатаны хорыг гадагшлуулахын тулд хором мөч бүрд Бурханд найдан, Бурханд хэрхэн ойртох талаар хором мөч бүрд сүнсэн дотроо хэрэгжүүлж, бүхий л оршихуйгаа Бурханаар ноёрхуулах учиртай.

7-Р БҮЛЭГ

Эргэн тойронд маань урган гарч ирэх нөхцөл байдал нь биднийг үтэр түргэн сүнсэндээ буцахад хүргэдэг. Ариун Сүнс санаа зовж байгаа эсэхийг үл тоомсорлон, хатуу зүрх сэтгэл бүү гарга, цэцэн цэлмэг байх гэж бүү оролд. Маадгар, сэхүүн зан бүү гарга, эсвэл өөрийн зовлон бэрхшээлийг их зүйлд бүү тооц. Бурханд сүнсээрээ, үнэнээр мөргөх нь хийх ганц зүйл юм. Бурханы үгийг гээж, эсвэл сонсоогүй мэт дүлий дүмбэ царайлж болохгүй; харин тэдгээрийг анхааралтай тунгааж, залбирлын уншлагаа давтаж, үгсэнд агуулагдах амийг олж авах ёстой. Өөртөө Бурханы үгийг шингээх зав өгөлгүй, яаран идэж, хуумгай зан бүү гарга. Чи хийж буй бүх зүйлдээ Бурханы үгэнд найддаг уу? Хүүхэд шиг том ярьчхаад, асуудал тохиолдох бүрд бантан бүү хутга. Өдөр бүр, цаг тутам чи сүнсээ дасгалжуулах ёстой, хором ч бүү амар. Сүнсээрээ соргог байх ёстой. Ямар хүн, үйл явдал, эсвэл зүйлтэй тулгарахаас үл хамааран, Бурханы өмнө ирэх аваас чи дагах замтай болно. Бурханы хүслийг буруу ойлгохоос зайлсхийх үүднээс чи Бурханы үгсийг өдөр бүр идэж ууж, хайхрамжгүй хандалгүйгээр утгыг нь тунгааж, илүү их хүчин чармайлт гарган, бүх жижиг зүйлийг ч нарийвчлан авч үзэж, өөрийгөө бүрэн үнэнээр зэвсэглэх ёстой. Чи туршлагынхаа хүрээг өргөтгөж, Бурханы үгийг амсаж туулахад анхаарлаа төвлөрүүлэх ёстой. Туршлагаар дамжуулан чи Бурханы тухайд илүү итгэлтэй байж чадна; туршлагагүйгээр Түүний тухайд итгэлтэй байна гэх нь хоосон үг төдий. Бид саруул ухаантай байх ёстой! Сэрцгээ! Цаашид бүү үлбэгэр бай; хэрвээ аливаа зүйлтэй хааш яаш харьцаж, ахиц гаргахын төлөө шамдахгүй байгаа бол чи үнэхээр сохор байна. Чи Ариун Сүнсний ажилд төвлөрч, Ариун Сүнсний дуу хоолойг анхааралтай сонсож, Бурханы үгсэд чих тавьж, үлдсэн цагаа нандигнаж, төлөөс нь ямар ч байлаа гэсэн төлөх ёстой. Чамд ган байгаа бол ир сайтай болгохын тулд үр ашигтайгаар ашигла; гол асуудалд сайтар төвлөрөн, Бурханы үгсийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуул. Бурханы үгсийг орхисон бол чи гаднаа хэчнээн сайн байлаа ч, энэ бүхэн ямар ч нэмэргүй. Амаараа хэрэгжүүлэх нь Бурханы хувьд хүлээн зөвшөөршгүй, өөрчлөлт өөрийн чинь ааш авир, зан чанар, итгэл, зориг, мэдлэг ухаанд гарах ёстой.

Цаг бараг болжээ! Чи энэ дэлхийн хамгийн сайхан зүйлсийг ч ардаа орхих

ёстой. Биднийг ямар ч их аюул, бэрхшээл айлгаж чадахгүй, тэнгэр нурлаа ч биднийг сандаргаж чадахгүй. Ийм төрлийн шийдэмгий байдалгүйгээр, чухал нэгэн болоход чамд хэтэрхий бэрх байх болно. Зүрх зориггүй, хулчгар байдлаар амьтайгаа зууралддаг хүмүүс Бурханы өмнө зогсох үнэ цэнгүй.

Төгс Хүчит Бурхан бол бодитой Бурхан. Бид хэчнээн тоомжиргүй байсан ч Тэр биднийг өрөвдөж, Түүний гар биднийг гарцаагүй аврах бөгөөд Тэр биднийг бүрэн төгс болгоно. Бид Бурханыг үнэхээр хүсдэг зүрх сэтгэлтэй байж, ойр даган, шантралгүй, яаран эрж хайж байгаа цагт, Тэр бидний хэнтэй ч шударга бус харьцахгүй, дутууг маань гүйцээж, биднийг хангана—энэ бүхэн Төгс Хүчит Бурханы сайхан сэтгэл билээ.

Хэрэв хүн ховдог агаад залхуу, үргэлжийн гэдэс цатгалан амьдралаар амьдран, бүх зүйлд анзааргагүй байдаг бол хохирол амсахаас зайлсхийхэд бэрх байх болно. Төгс Хүчит Бурхан бүх зүйл, бүх хэрэг явдлыг захирдаг! Бид зүрх сэтгэлдээ Түүнийг цаг ямагт хүндэлж, сүнсэнд орж, Түүнтэй нөхөрлөж байгаа цагт Тэр эрж хайдаг бүх зүйлийг маань бидэнд үзүүлэх ба Түүний хүсэл бидэнд илчлэгдэх нь гарцаагүй. Тэр үед зүрх сэтгэл маань баяр баясалтай, амар амгалан, бүрэн тодорхой байдалд тайван байх болно. Түүний үгийн дагуу үйлдэж чаддаг байх нь маш чухал юм. Түүний хүслийг ухаарч, Түүний үгэнд найдаж амьдрах чадвартай байх нь л жинхэнэ туршлагад тооцогдоно.

Бурханы үгийг ойлгосноор л Бурханы үгийн үнэн бидэн рүү орж, бидний амь болж чадна. Ямар ч бодит туршлагагүйгээр чи Бурханы үгийн бодит байдалд хэрхэн орж чадах билээ? Хэрвээ Бурханы үгийг өөрийн амь болгон хүлээн авч чадахгүй бол зан чанар чинь өөрчлөгдөх боломжгүй байх болно.

Ариун Сүнсний ажил эрчимтэй урагшилж байна! Хэрвээ чи ойроос дагаж, сургалт хүлээн авахгүй бол Ариун Сүнсний цойлох алхаатай хөл нийлүүлэхэд хэцүү байх болно. Яаравчилж, эрс өөрчлөлтийг авчир, эс бөгөөс чи Сатаны хөлд дэвслүүлж, гарах боломжгүй гал болон хүхэрт нууранд унах вий. Одоо яв, чадах чинээгээрээ эрж хай, тэгж байж чи хөсөр хаягдахгүй.

8-Р БҮЛЭГ

Төгс Хүчит Бурхан—хаанчлалын Хаан гэрчлэгдсэнээс хойш Бурханы удирдлагын цар хүрээ бүх орчлон ертөнц даяар бүрэн дэлгэрчээ. Бурханы илрэлт Хятадад гэрчлэгдээд зогсохгүй, Төгс Хүчит Бурханы нэр бүх улс үндэстэн, бүх газар нутагт гэрчлэгдсэн юм. Тэд бүгд энэ ариун нэрийг дуудаж, боломжтой бүх аргаар Бурхантай нөхөрлөхийг эрмэлзэж, Төгс Хүчит Бурханы хүслийг ухаарч, чуулган дотор уялдаа холбоотой үйлчилж байна. Ариун Сүнс ийм гайхалтайгаар ажилладаг.

Янз бүрийн улс үндэстний хэл нэг нэгээсээ ялгаатай байдаг боловч цорын ганц Сүнс бий. Энэ Сүнс орчлон ертөнц даяарх чуулгануудыг нэгтгэдэг бөгөөд өчүүхэн

ч ялгаагүйгээр Бурхантай туйлын нэг юм, энэ бол эргэлзэх аргагүй зүйл билээ. Ариун Сүнс одоо тэднийг дуудаж байгаа бөгөөд Түүний дуу хоолой тэднийг сэрээж байна. Энэ бол Бурханы өршөөлийн дуу хоолой юм. Тэд бүгд Төгс Хүчит Бурханы ариун нэрийг дуудаж байна! Тэд бас магтаал өргөж, дуулдаг. Ариун Сүнсний ажилд ямар нэг гажуудал огтхон ч байх боломжгүй бөгөөд энэ хүмүүс зөв замын дагуу урагшлахын тулд шаардлагатай бүхнийг хийдэг, тэд эргэж буцдаггүй ба гайхамшгууд нь ар араасаа овоордог. Энэ бол хүмүүс төсөөлөхөд хэцүү, таамаглах боломжгүй зүйл юм.

Төгс Хүчит Бурхан бол орчлон ертөнц дэх амийн Хаан билээ! Тэрээр алдар суут сэнтийд заларч, дэлхийг шүүж, бүгдийг ноёлж, бүх улс үндэстнийг захирдаг. Бүх хүн Түүнд өвдөг сөгдөж, Түүнд залбирч, Түүнд ойртож, Түүнтэй ярилцдаг. Чи Бурханд хэчнээн удаан итгэсэн ч бай, байр суурь чинь хэчнээн өндөр ч бай, зэрэг зиндаа чинь хэчнээн дээгүүр ч бай, зүрх сэтгэлдээ Бурхантай сөргөлдөх юм бол шүүгдэх ёстой бөгөөд Түүний өмнө нүүрээрээ газар унан мөргөж, шаналалтайгаар гуйх чимээ гаргах ёстой; энэ нь үнэндээ өөрийнхөө үйлдлийн үр жимсийг хурааж байгаа хэрэг юм. Энэхүү уйлах дуу чимээ бол гал ба хүхэрт нуурт тарчилж буй дуу бөгөөд Бурханы төмөр саваагаар гэсгээгдэж буй хашхираан мөн; энэ нь Христийн суудлын өмнөх шүүлт билээ.

Зарим хүн айдаг, зарим нь буруугаа ухамсарладаг, зарим нь сэргэг байж, зарим нь анхааралтай сонсохоор хичээдэг, зарим нь гэмшиж, шинээр эхлэн, туйлын их харуусдаг, зарим нь гашуунаар шаналан уйлдаг, зарим нь бүгдийг орхиж, цөхрөнгүйгээр хайдаг, зарим хүн өөрсдийгөө шинжилж, дахин цадиггүй аашилж зүрхэлдэггүй, зарим нь Бурханд ойртох гэж яаравчлан эрж хайдаг, зарим нь өөрсдийн мөс чанарыг шинжилж, амь нь яагаад ахихгүй байгааг асуудаг. Зарим нь самуурсан хэвээр үлддэг, зарим нь хөлийнхөө дөнгийг мулталж, зоригтойгоор урагшилж, гол зүйлийг ухаарч, цаг алдалгүй амиа анхаардаг. Зарим нь мөн л тээнэгэлзэж, үзэгдлүүдийн талаар тодорхой мэддэггүй—зүрх сэтгэлдээ үүрдэг тэдний ачаа үнэндээ хүнд байдаг.

Хэрэв чиний бодол санаа тодорхойгүй бол Ариун Сүнс дотор чинь ажиллах аргагүй. Чиний анхаарлаа төвлөрүүлдэг бүхэн, алхдаг зам, зүрх сэтгэлээсээ хүсдэг бүхэнд чиний үзэл болон өөрийгөө зөвтгөдөг байдал дүүрэн бий! Би тэсэн ядаж байна—та нарыг бүгдийг чинь нэн даруй бүрэн төгс болгох сон гэж Би хэчнээн их хүснэ вэ, тэгэх юм бол та нар удалгүй Надад хэрэгтэй болж, Миний хүнд ачаа хөнгөрөх боломжтой болно. Гэвч та нарыг харахад үр дүнд яараад нэмэргүй нь илт. Би тэвчээртэй хүлээж, аажуухан алхаж, алгуурхнаар та нарыг дэмжиж, удирдаж л чадах юм байна. Ай, та нар тархиа сэргээх хэрэгтэй! Юуг хаях ёстой, үнэт эрдэнэ чинь юу болох, хөнөөлт сул тал чинь юу болох, саад бэрхшээл чинь юу болохыг сүнсэн дотроо илүү их тунгаан бодож, Надтай илүү их нөхөрлө. Миний хүсдэг зүйл бол зүрх сэтгэл чинь чимээгүйхнээр Намайг хүндлэх болохоос хэл амаараа үйлчлэх чинь Надад хэрэггүй. Миний өмнө үнэхээр эрж хайдаг хүмүүст Би бүгдийг

илчилнэ. Миний алхаа түргэсэж байна; зүрх сэтгэл чинь Намайг хүндэлж, цаг ямагт дагаж л байвал Миний хүсэл хэдийд ч чамд онгодоор өгөгдөж, илчлэгдэж чадна. Хүлээхэд анхаардаг хүмүүс тэжээл хүртэж, урагшлах замтай болно. Бодлогогүй хүмүүс Миний зүрх сэтгэлийг ойлгож цөхөх бөгөөд мухар зам руу алхана.

Та нар бүгд хурдан босоод Надтай хамтран ажиллаж, ердөө ганцхан өдөр, шөнө биш, харин цаг ямагт Над руу ойртоосой гэж Би хүсдэг. Миний гар та нарыг байнга татаж чангааж, цохиж, түлхэж, урагшлуулахаар ятгаж, цааш явуулахаар уриалах ёстой болдог! Та нар Миний хүслийг ердөө ойлгодоггүй. Та нарын үзлийн саад бартаа, энэ ертөнцийн ээдрээ бартаа дэндүү ноцтой байдаг бөгөөд та нар Надтай илүү гүн дотносох чадваргүй. Шулуухан хэлэхэд, та нар асуудалтай байх үедээ Над руу ирдэг, харин ямар ч асуудал байхгүй бол зүрх сэтгэл чинь түгшдэг. Зүрх сэтгэл чинь чөлөөт зах зээл мэт болж, сатанлаг зан чанараар дүүрч, ертөнцийн зүйлсэд эзлэгддэг бөгөөд Надтай яаж нөхөрлөхөө мэддэггүй. Би яаж та нарын төлөө санаа зовохгүй байх юм бэ? Гэвч санаа зовоод нэмэргүй. Цаг хугацаа дэндүү давчуу, хийх ажил шахуу байна. Миний алхам хурдалж байна; та нар өөрт байгаа бүхнээ хатуу баримталж, хором бүрд Над руу харж, Надтай ойр дотно нөхөрлөх ёстой. Тэр цагт Миний хүсэл хэдийд ч чамд илчлэгдэх нь гарцаагүй. Миний зүрх сэтгэлийг ойлгох үедээ та нар урагшлах замтай байдаг. Цаашид бүү тээнэгэлз. Надтай жинхэнэ нөхөрлөл хий, тэгээд заль мэхэнд бүү найд, хэтэрхий ухаантай байх гэж бүү хичээ; тэгэх нь өөрсдийгөө л хуурч буй хэрэг бөгөөд Христийн суудлын өмнө хэзээ хэзээгүй илчлэгдэнэ. Жинхэнэ алт галаар шалгуулахаас айдаггүй—энэ бол үнэн! Бүү эргэлз, бүү зүрх алд, сул дорой бүү бай. Сүнсээрээ Надтай шууд нөхөрлөж, тэвчээртэй хүлээ, тэгээд Би чамд Өөрийнхөө цагийн дагуу заавал илчилнэ. Чи үнэхээр, туйлаас болгоомжтой байж, чамд гаргасан Миний хичээл зүтгэлийг талаар өнгөрүүлэх ёсгүй, хором мөчийг бүү алд. Зүрх сэтгэл чинь Надтай байнга нөхөрлөдөг бол, зүрх сэтгэл чинь байнга Миний өмнө амьдардаг бол хэн ч, ямар ч үйл явдал, зүйлс, мөн ямар ч нөхөр, ямар ч хүү, охин зүрх сэтгэлдээ Надтай нөхөрлөхөд чинь саад хийж чадахгүй. Чиний зүрх сэтгэл Ариун Сүнсэнд байнга хязгаарлагдаж, чи хором бүрд Надтай нөхөрлөж байвал Миний хүсэл чамд заавал илчлэгдэнэ. Чи өөрийнхөө эргэн тойрон, байгаа нөхцөл байдлаасаа үл шалтгаалан ийм маягаар байнга Надад ойртох үед хэнтэй ч, юутай ч учирсан будилж төөрөлдөхгүй бөгөөд урагшлах замтай байх болно.

Том, жижиг асуудлууд дээр аливааг орхигдуулахыг чи ерөнхийдөө зөвшөөрдөггүй бол, зүрх сэтгэл, бодол санаа чинь ариуссан бол, сүнсэндээ тайван байдаг бол асуудалтай тулгарах болгонд чинь өөрийгөө харах тод толь мэтээр Миний үг чиний дотор нэн даруй онгод оруулж, чи урагшлах замтай болно. Үүнийг зөв өвчинд зориулсан зөв эм гэж нэрлэдэг! Ямар ч өвчин заавал эдгэрнэ—Бурхан бол ийм төгс хүчит. Зөвт байдлын төлөө өлсөж цангадаг, чин сэтгэлээсээ хайдаг бүх хүнийг Би заавал гэрэлтүүлж, гэгээрүүлнэ. Би та бүхэнд сүнсний ертөнцийн бүх нууц болон урагшлах замыг харуулж, хуучин ялзарсан зан чанарыг чинь аль болох хурдан

хаяулна, ингэснээр амь чинь төлөвшиж, Надад ашиглагдахад тохирохуйц болж, сайн мэдээний ажил удалгүй саадгүйгээр урагшилж болох юм. Тэр үед л Миний хүсэл ханана, тэр үед л Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө аль болох хурдан гүйцэлдэнэ. Бурхан хаанчлалыг олж авч, газар дэлхий рүү бууж ирнэ, тэгээд бид хамтдаа алдар луу орно!

9-Р БҮЛЭГ

Миний үгийн талаар өчүүхэн ч болов тодорхойгүй зүйл, хайхрамжгүй хандлага байж болохгүй гэдгийг Би чамд сануулмаар байна. Чи анхааралтай сонсож, дуулгавартай дагаж, Миний санаа зорилгод нийцүүлэн хэрэгжүүлэх ёстой. Чи үргэлж сэргэг байж, хэзээ ч биеэ тоосон, өөрийгөө зөвтгөдөг зан чанар гаргах ёсгүй, мөн дотор чинь оршиж ирсэн төрөлхийн хуучин зан чанараасаа салахын тулд Надад үргэлж найдах ёстой. Миний өмнө үргэлж хэвийн байр байдлаа хадгалж, тогтвортой зан чанартай байж чаддаг байх хэрэгтэй. Бодож сэтгэх чинь үргэлж эрүүл саруул байх ёстой бөгөөд аливаа хүн, үйл явдал, юмст захирагдаж, ганхаж болохгүй. Чи Миний өмнө үргэлж тайван байж, Надтай байнга ойр байж, нөхөрлөх хэрэгтэй. Хүч чадал, ноён нуруу гаргаж, Намайг гэрчлэхдээ бат зогсох ёстой. Босоод Миний өмнөөс ярь, бусад хүн юу гэхээс бүү ай. Зүгээр л Миний санаа зорилгыг биелүүлж, хэнд ч өөрийгөө удирдах боломж бүү олго! Чамд Миний илчлэх зүйлийг Миний санаа зорилгод нийцүүлэн хийх ёстой ба хойшлуулж болохгүй. Сэтгэлийнхээ гүнд юу мэдэрч байна даа? Тав тухгүй байгаа биз? Чи ойлгох болно. Чи яагаад Миний ачааг бодолцож үзэнгээ босоод Миний өмнөөс үг хэлчхэж чадахгүй байгаа юм бэ? Чи ялихгүй явуулгад оролцсоор байгаа ч энэ бүхнийг чинь Би тодорхой хардаг. Би бол чиний дэмжлэг, чиний бамбай, мөн бүх зүйл Миний гарт байдаг. Гэтэл чи юунаас айна вэ? Сэтгэл хөдлөлдөө хэт автаад байгаа юм биш үү? Чи сэтгэл хөдлөлөө үтэр түргэн хаях ёстой; Би сэтгэлийн хөөрлөөрөө үйлддэггүй, оронд нь зөвт байдлыг хэрэгжүүлдэг. Эцэг эх чинь ямарваа нэг чуулганд ашиг тусгүй юм хийдэг бол тэд мултарч чадахгүй. Миний санаа зорилго чамд илчлэгдсэн, чи үүнийг үл тоож болохгүй. Харин ч чи бүх анхаарлаа үүнд хандуулж, үнэн сэтгэлээсээ дагахын тулд бүхнийг хойш тавих ёстой. Би чамайг үргэлж Өөрийн гарт байлгана. Битгий байнга айн хулчийж, нөхөр юм уу эхнэртээ захирагд; чи Миний хүслийг биелүүлэх ёстой.

Итгэл үнэмшилтэй бай! Итгэл үнэмшилтэй бай! Би бол чиний төгс хүчит. Магадгүй чи энэ талаар бага зэрэг ойлголттой байх, гэхдээ л сэрэмжтэй байх ёстой. Чуулган, Миний хүсэл, Миний удирдлагын төлөө чи бүхнээ зориулах ёстой бөгөөд бүх нууц болон үр дагаврыг чамд тодорхой харагдуулах болно. Цаашид дахин хойшлогдохгүй ба өдөр хоногууд эцэс болж байна. Тэгвэл чи юу хийх хэрэгтэй вэ? Өөрийн амийг илүү хурдан төлөвшүүлэхийн тулд хэрхэн эрж хайж болох вэ? Өөрийгөө яаж хурдхан шиг Надад хэрэгтэй болгох вэ? Миний хүсэлд хэрэгжих

боломжийг чи хэрхэн олгох вэ? Эдгээр асуулт сайтар тунгааж, Надтай гүн гүнзгий нөхөрлөхийг шаарддаг. Надад найд, Надад итгэ, хэзээ ч хайнга бүү бай, аливааг Миний удирдамжид нийцүүлэн үйлдэх чадвартай бай. Үнэнээр сайтар зэвсэглэж, үүнийг илүү их идэж, уух ёстой. Үнэн бүрийг хэрэгжүүлэх ёстой ба тэгвэл тодорхой ойлгож чадна.

Хангалттай цаг байхгүйг одоо чи мэдэрч байна уу? Бас дотор чинь чи өмнөхтэйгөө харьцуулахад өөр мэт, мөн ачаа чинь маш хүнд мэт санагдаж байна уу? Миний санаа зорилго чам руу чиглэдэг; чи сэргэг байж, санаа зорилгоос минь салах ёсгүй, Надтай үргэлж холбоотой бай. Надтай ойр хэвээр бай, Надтай ярилц, Миний зүрх сэтгэлийг хайхар, мөн бусадтай уялдаатай үйлчилж чаддаг бай, тэгж байж Миний санаа зорилго та нарт үргэлж илчлэгдэнэ. Байнга сайтар анхааралтай ажигла! Сайтар анхаар! Жаахан ч гэсэн бүү хойргол; энэ бол чиний үүрэг, Миний ажил үүнд оршдог.

Чи одоогоор багахан ойлголт олж авчхаад түүнийгээ үнэхээр гайхалтай мэтээр сэтгэж байгаа байх. Өнгөрсөнд чамд эргэлзээ төрж, хүний ойлголт, санаа, бодлоос тэс өөр юм гэж санагдсан байж болох ч одоо бол чи ерөнхийд нь ойлгож байгаа. Энэ бол Миний гайхалтай ажил, Бурханы ч гайхалтай ажил билээ. Чи Бурханы ажил дотор алхахдаа туйлын сонор сэргэг байж, хүлээх ёстой. Цаг хугацаа Миний гарт байна; дэмий бүү үр, нэг хором ч бүү хойргол. Цаг үрэх нь Миний ажлыг хойшлуулж, чиний доторх Миний хүсэлд саад хийдэг. Чи ойр ойрхон тунгаан бодож, Надтай нөхөрлөх ёстой. Чи мөн бүх үйлдэл, хөдөлгөөн, бодол, санаа, гэр бүл, нөхөр, хөвгүүд, охидоо Миний өмнө авчрах ёстой. Хэрэгжүүлэлтдээ өөртөө найдах хэрэггүй, эс бөгөөс Би хилэгнэж, чамд томоохон гарз хохирол учрах болно.

Цаг үргэлж өөрийн алхмыг дөрлөж, үргэлж Миний үгэн дотор алх. Чамд Миний мэргэн ухаан байх ёстой. Хүндрэл бэрхшээл тулгарвал Миний өмнө ир, Би чамд удирдамж өгнө. Битгий хэрэг тарьж эсвэл хамаа намаагүй ярилц. Хэрвээ амь чинь ямар ч ашиг тус хүртээгүй бол чамд мэдлэг дутаж, сайн, муу үгийг ялгаж чаддаггүйгээс чинь болж байгаа юм. Хор хөнөөл амсаж, нөхцөл байдал чинь дордож, Ариун Сүнс дэргэдээс чинь үгүй болох хүртэл чи үүнийг ухаардаггүй. Гэвч тэр үед хэтэрхий оройтсон байдаг. Цаг одоо үнэхээр давчуу байгаа учир амийн уралдаанд чи өчүүхэн ч болов хоцрох ёсгүй; чи Миний мөрийг ойрхон дагах ёстой. Ямар нэг бэрхшээл гарч ирэхэд Надад ойр байх замаар байнга тунгаан бодож, Надтай шууд нөхөрлө. Хэрвээ чи энэ замыг ухаарч чадвал урд чинь буй оролт хялбар болно.

Миний үг ганцхан чамд чиглэсэн юм биш; чуулганы бүх хүн төрөл бүрийн талын дутагдалтай байдаг. Та нар илүү их нөхөрлөж, сүнслэг үйл ажиллагааныхаа үеэр бие даан идэж, уух чадвартай байж, гол үнэнийг ухаарч, тэдгээрийг даруйхан хэрэгжүүлж чаддаг байх ёстой. Чи Миний үгийн бодит байдлыг мэдрэх ёстой: гол цөм болон зарчмыг нь атгаад ав, тэгээд гараа бүү сул тавь. Байнга тунгаан бодож, Надтай үргэлж нөхөрлө, тэгвэл аажмаар юмс илчлэгдэнэ. Чи Бурханд нэг хэсэг ойртсоноо, дараа нь зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван болохыг хүлээлгүй, өөр

зүйл тохиолдох үед үймрээд байж болохгүй. Чи үргэлж будилж, аливаа зүйлийн талаар эргэлзэн, Миний царайг харах чадваргүй байдаг тул зүрх сэтгэлийг минь тодорхой ойлгож чаддаггүй. Бага зэрэг ойлгож чадлаа ч гэсэн чи итгэлтэй биш, эргэлзсээр байдаг. Би чиний зүрх сэтгэлийг бүхэлд нь эзэмшиж, оюун ухаан чинь ертөнцийн аливаа зүйлд үймрэхээ больж, тайван, саруул ухаанаар хүлээх тэр үед чинь Би та нарт Өөрийн санаа зорилгын дагуу нэг нэгээр нь илчлэл хийнэ. Та нар Надтай ойр байх энэ замыг ойлгох ёстой. Чамайг хэн ч дайрч, эсвэл хараасан бай, эсвэл хэчнээн сайхан зүйл санал болгосон бай, тэд Бурхантай ойр байхад чинь саад хийх л юм бол үүнийг зөвшөөрч болохгүй. Зүрх сэтгэлээ Миний гарт даатгаж, Намайг хэзээ ч бүү орхи. Ийм ойр дотно байж, нөхөрлөж байхад, эцэг эх, нөхөр, хүүхэд, гэр бүлийн бусад харилцаа, эсвэл энэ ертөнцийн холбоо сүлбээ ч бай, бүгд холдон одно. Чи зүрх сэтгэлдээ бараг үгээр дүрслэхийн аргагүй жаргалыг эдэлж, анхилам, тансаг амтыг мэдэрч, тэрнээс ч илүүтэйгээр Надаас үнэхээр салшгүй болно. Хэрвээ үргэлж ийм байвал, зүрх сэтгэлд минь юу байдгийг та нар ойлгоно. Урагш ахихдаа та нар хэзээ ч замаа алдахгүй, учир нь Би та нарын зам бөгөөд бүх зүйл Надаас болж оршин тогтнодог. Амь чинь хэр төлөвших, чи энэ дэлхий ертөнцийн аж байдлаас хэзээ салж явж чадах, хэзээ сэтгэл хөдлөлөө хаяж, нөхөр хүүхдээ орхиж чаддаг болох, амь чинь хэзээ төлөвших … энэ бүх зүйл Миний төлөвлөгөөний дагуу тохиолдоно. Сэтгэл түгших хэрэггүй.

Чи эерэг талаас орох ёстой. Хэрвээ идэвхгүй байдлаар хүлээх юм бол сөрөг байсаар байх болно. Надтай хамтарч ажиллахдаа санаачилгатай байх ёстой; ажилч хичээнгүй бай, хэзээ ч бүү залхуур. Надтай үргэлж нөхөрлө, Надтай гүнээ ойр дотно бай. Хэрвээ ойлгохгүй бол, үр дүнд хурдан хүрэхийн төлөө тэвчээргүй загнаж болохгүй. Би чамд хэлэхгүй юм биш; Миний өмнө байхдаа Намайг түшиж тулдаг эсэхийг чинь, мөн итгэлтэйгээр Надад найддаг эсэхийг чинь хармаар байна. Чи үргэлж Надтай ойрхон байж, бүх асуудлыг Миний гарт даатгах ёстой. Битгий хий хоосон буц. Надтай хэсэг хугацаанд өөрийн мэдэлгүй ойр байсны дараа, Миний санаа зорилгууд чамд илчлэгдэнэ. Хэрвээ чи тэдгээрийг ухаарвал Надтай үнэхээр нүүр тулан уулзах бөгөөд Миний нүүр царайг үнэхээр олсон байх болно. Чи дотроо нэлээд тодорхой, тогтвортой байх бөгөөд найдах зүйлтэй болно. Тэгээд чи бас хүч чадал болон итгэлийг олж авах бөгөөд чамд бас урагшлах зам байх болно. Бүх зүйл чамд хялбархан байх болно.

10-Р БҮЛЭГ

Чи энэнээс ч нэг, тэрнээс ч нэг айх хэрэггүй; Хэчнээн олон бэрхшээл, аюултай тулгарч магадгүй ч гэсэн чи ямар ч сааданд түүртэлгүй Миний өмнө тууштай байх чадвартай байна, тэгж Миний хүсэл саадгүй хэрэгжиж болно. Энэ чиний үүрэг; эс бөгөөс Би уур хилэнгээ чам дээр буулгаж, Өөрийн гараар … Тэгээд чи эцэс

төгсгөлгүй сэтгэлийн зовлон үзнэ. Чи бүхнийг тэвчих ёстой; чи байгаа бүхнээ орхиход бэлэн, Намайг дагахын тулд чадах бүхнээ хийж, Миний төлөө бүхнээ зарцуулахад бэлэн байх ёстой. Одоо бол Би чамайг шалгах цаг, Надад чи үнэнч байх уу? Намайг чи замын төгсгөл хүртэл үнэнчээр дагаж чадах уу? Бүү ай; Миний дэмжлэг байхад энэ замыг хэн хааж чадах билээ? Үүнийг сана! Бүү март! Тохиолдсон бүх зүйлд Миний сайн санаа зорилго бий, бүгд Миний ажиглалт дор байдаг. Чи үг, үйлдэл бүртээ Миний үгийг дагаж чадах уу? Галын шалгалтууд чам дээр ирэхэд чи өвдөг сөгдөж, хашхирах уу? Эсвэл, урагш явж чадахгүй бээцийх үү?

Чи дотроо Миний зоригийг тээж, итгэдэггүй төрөл төрөгсөдтэйгөө нүүр тулахдаа зарчимтай байх ёстой. Харин чи бас Миний төлөө ямар ч харанхуй хүчинд бууж өгөх ёсгүй. Төгс замаар алхахын тулд Миний мэргэн ухааныг түш; Сатаны хуйвалдаан биелэх боломж бүү олго. Миний өмнө зүрх сэтгэлээ байлгахад бүх хүчин чармайлтаа гарга, Би чамайг тайтгаруулж, амар амгалан, баяр хөөр авчирна. Бусад хүний өмнө тодорхой байдлаар авирлах гэж бүү тэмүүл; Намайг хангалуун байлгах нь илүү үнэ цэнэтэй, чухал биш гэж үү? Намайг хангалуун байлгахдаа чи үүрдийн, насан туршийн баяр хөөр, амар амгалангаар бүр ч илүү их дүүрэн болохгүй гэж үү? Чиний одоогийн зовлон ирээдүйн ерөөл чинь хэчнээн агуу байхыг илтгэдэг; үүнийг дүрслэхийн аргагүй. Чи хэчнээн агуу ерөөл авахаа мэдэхгүй, үүний тухай мөрөөдөж ч чадахгүй. Өнөөдөр энэ бодитой болсон; маш бодитой! Энэ төдий холгүй байна, чи харж чадах нь уу? Үүний өчүүхэн хэсэг бүр нь Миний дотор бий; урдах зам ямар их гэгээтэй байна гээч! Нулимсаа арч, зовлон, уй гунигийг дахин бүү мэдэр. Бүх юмыг Миний гар зохицуулсан, Миний зорилго гэвэл, та нарыг удалгүй ялагчид болгож, Өөртэйгөө хамт алдар сууд аваачих явдал юм. Чи өөрт тохиолдсон бүхний төлөө нийцүүлэн талархаж, үлэмж магтах ёстой; тэгснээр Миний зүрх сэтгэлийг ихэд хангалуун болгоно.

Христийн ер бусын амь хэдийн илэрсэн; чамд айх зүйл юу ч үгүй. Сатанууд бидний хөл дор байгаа ба тэдний цаг нэг их удахгүй. Сэр! Садар самууны хорвоог хөсөр хая; үхлийн ангалаас өөрийгөө чөлөөл! Юу болсон ч хамаагүй, Надад үнэнч байж, зоригтойгоор урагшил; Би бол чиний бат бөх хад, тиймээс Намайг түш!

11-Р БҮЛЭГ

Би чиний Бурхан мөн үү? Би чиний Хаан мөн үү? Намайг дотор чинь Хаан болон захирахыг чи үнэхээр зөвшөөрсөн үү? Чи өөрийгөө сайтар эргэцүүлэх хэрэгтэй. Чи шинэ гэрлийг ирэхэд нь шинжилж, голж, тэр бүү хэл дагалгүй зогссон биш гэж үү? Үүнийхээ төлөө чи шүүлтийг туулж, мөхөл рүүгээ унаж, мөн шүүгдэж, төмөр саваагаар саваадуулах бөгөөд Ариун Сүнсний ажлыг мэдрэхгүй байх болно. Мөдхөн чи цурхиран уйлж, орилон, өвдөг сөхрөн шүтэн мөргөнө. Би та нарт үргэлж хэлж байсан, Би та нарт үргэлж ярьж байсан; Би үгээ хэзээ ч та нараас харамлаж

байгаагүй. Эргээд сайн бод доо, Би хэзээ ер нь та нарт ямар нэгэн зүйл хэлж чадахгүй байлаа даа? Гэлээ ч, аливааг буруу арга замаар хийх гэж зүтгэдэг зарим хүн бий. Тэд, нарыг халхалдаг эргэлзээний манан дунд төөрч, гэрэл хэзээ ч үздэггүй. Энэ нь тэдний “би”-ийн ухамсар хэт хүчтэйгээс, үзэл нь хэтэрхий их байгаагаас үүдсэн биш гэж үү? Хэзээ чи Намайг анхаардаг байсан юм бэ? Хэзээ зүрх сэтгэлд чинь Намайг гэх орон зай байсан юм бэ? Чи бүтэлгүйтэж, чадамжгүй гэдгээ ойлгож, ямар ч сонголтгүй болсон үедээ л Надад залбирдаг. Тэгвэл чи одоогоос аливааг өөрийнхөөрөө хийвэл яасан юм бэ? Хүмүүс, та нар! Хуучин төрх чинь л чамайг сүйрүүллээ!

Зарим хүн замыг олж, шинэ гэрэлтэй хөл нийлүүлж чаддаггүй. Тэд өмнө нь үзэж харсан юмныхаа тухай л нөхөрлөдөг; тэдэнд шинэ зүйл гэж үгүй. Яагаад тэр вэ? Чи өөрийнхөө дотор амьдарч, Намайг оруулалгүй үүдээ хаасан. Ариун Сүнсний ажлын арга барил өөрчлөгдөхийг хараад зүрх сэтгэлдээ чи буруу байх вий хэмээн үргэлж хаширладаг. Бурханыг гэх хүндлэл чинь хаана байна вэ? Чи үүнийг Бурханы өмнө тайвнаар эрж хайсан уу? Чи ердөө л “Ариун Сүнс үнэхээр ингэж ажилладаг гэж үү?” хэмээн гайхширдаг. Зарим хүний харсан зүйл нь Ариун Сүнсний ажил хэдий ч тэдэнд энэ талаар хэлэх зүйл байсаар л байдаг; зарим нь үүнийг Бурханы үг гэдгийг зөвшөөрдөг ч хүлээн авдаггүй. Тэдний нэг бүрийнх нь дотор янз бүрийн үзэл улам нэмэгдэж, тэд Ариун Сүнсний ажлыг ойлгодоггүй. Тэд хайнга, болгоомжгүй байж, Миний өмнө төлөөс төлж, чин үнэнч байхыг хүсдэггүй. Ариун Сүнс өөрсдийг нь гэгээрүүлсэн ч тэд ярилцаж, эрж хайхаар Миний өмнө ирэхгүй. Харин ч тэд хүслээ дагаж, юу дуртайгаа хийдэг. Энэ ямар гээч санаа зорилго вэ?

12-Р БҮЛЭГ

Хэрвээ чи салхи бороо шиг хувьсамтгай, тогтворгүй зан чанартай бол, хэрвээ чи бүх чадлаараа урагш тэмүүлсээр байж чаддаггүй бол Миний саваа чамаас холдохгүй. Чамтай харьцаж байх үед орчин чинь хэцүү байх тусам, их хавчигдах тусам, Бурханыг гэх хайр чинь улам өсөж, дэлхий ертөнцтэй зууралдахаа болино. Чи өөр замгүйгээр Над дээр ирж, хүч чадал, итгэлээ дахин олж авна. Гэвч, хялбар орчинд чи будилж орхих байсан. Чи эерэг талаас орж, идэвхгүй бус, идэвхтэй байх ёстой. Ямар ч нөхцөлд, хэнд ч, юунд ч ганхахгүй байх учиртай, бас хэний ч үгийн нөлөөнд автаж болохгүй. Чи тогтвортой зан чанартай байх ёстой ба хүмүүс юу ч гэсэн, үнэн гэж мэддэг зүйлээ даруй хэрэгжүүлэх учиртай. Хэнтэй ч нүүр тулж байсан, дотор чинь үргэлж Миний үг ажиллаж байх ёстой; Надад хийсэн гэрчлэлдээ бат зогсож, Миний ачаанд анхаарал хандуулж чаддаг байх ёстой. Чи өөрийн гэх санаа бодолгүйгээр хүмүүстэй сохроор санаа нийлж болохгүй; харин ч бат зогсож, үнэнтэй нийцдэггүй зүйлсээс татгалзах зоригтой байх ёстой. Хэрвээ чи ямар нэг зүйл буруу байгааг тодорхой мэдсэн ч илчлэх зориг хүрдэггүй бол үнэнийг

хэрэгжүүлдэг хүн биш. Чи ямар нэгэн зүйл хэлэхийг хүссэн ч шууд хэлж зүрхэлдэггүй тул тойруулан яриад, дараа нь сэдвийг өөрчилдөг; Сатан дотроос чинь чамд саад хийж, чамайг ямар ч үр нөлөөгүй ярьж, эцсээ хүртэл тууштай байж чадахгүйд хүргэдэг. Чи зүрх сэтгэлдээ айдас тээсээр байгаа нь зүрх сэтгэл чинь Сатаны санаа бодлоор дүүрэн хэвээр байгаагаас болдог биш үү?

Ялагч гэж юу вэ? Христийн сайн цэргүүд сүнсээрээ хүчтэй байхын тулд зоригтой байж, Надад найдах ёстой; тэд дайчин болж, Сатантай үхтэлээ тулалдахын тулд тэмцэх ёстой. Чи үргэлж сэрүүн байх ёстой, ийм учраас Би чамаас хором бүрд Надтай идэвхтэйгээр хамтран ажиллаж, Надад ойртож сурахыг шаарддаг. Хэрвээ чи ямар ч цаг үе, ямар ч нөхцөл байдалд Миний өмнө тайван байж, Миний яриаг сонсож, Миний үг, үйлдэлд анхаарал тавьж чаддаг бол гуйвж, сулрах учиргүй. Надаас хүлээж авдаг бүхэн чинь хэрэгжих боломжтой. Миний үг бүр чиний нөхцөл байдалд чиглэсэн. Тэд чиний зүрх сэтгэлийг сүлбэх ба чи тэдгээрийг амаараа үгүйсгэлээ ч гэсэн зүрх сэтгэлдээ үгүйсгэж чадахгүй. Түүнээс гадна хэрвээ чи Миний үгийг шинжвэл өөрөө шүүгдэнэ. Өөрөөр хэлбэл, Миний үг бол үнэн, амь, зам бөгөөд Сатаныг ялж чадах, хоёр иртэй хурц илд юм. Миний үгийг ойлгодог, хэрэгжүүлэх замтай хүмүүс ерөөгддөг ба хэрэгжүүлдэггүй хүмүүс зайлшгүй шүүгдэнэ; энэ бол үнэхээр бодитой юм. Одоо, Миний шүүдэг хүмүүсийн хүрээ өргөжсөн. Би Өөрийнхөө өмнө Намайг мэддэг хүмүүсийг шүүгээд зогсохгүй, Надад итгэдэггүй, Ариун Сүнсний ажлыг бүх чадлаараа эсэргүүцэж, саад болохыг оролддог хүмүүсийг ч бас шүүх болно. Миний өмнө Миний мөрийг дагаж буй бүх хүн Бурхан бол дүрэлзэж буй гал гэдгийг харна! Бурхан бол сүр жавхлан! Тэр Өөрийн шүүлтийг явуулж, тэдэнд үхэх ял оноож байна. Чуулганд буй, Ариун Сүнсний ажлыг дагахад анхаарал хандуулдаггүй, Ариун Сүнсний ажилд саад болдог, өөрсдийгөө гайхуулдаг, шударга бус санаа зорилготой, Бурханы үгийг идэж уухад хүчин чармайлт гаргадаггүй, будилуу, сэжиглэмтгий, Ариун Сүнсний ажлыг шинждэг хүмүүст—шүүлтийн үг хэдийд ч хамаагүй ирнэ. Хүмүүсийн бүх үйлдэл илчлэгдэнэ. Ариун Сүнс, хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг, иймээс бодлогогүй бүү бай; болгоомжтой, хашир бай, битгий өөрөө сохроор үйлд. Хэрвээ үйлдэл чинь Миний үгийг дагадаггүй бол чи шүүгдэнэ. Даган дуурайж, хуурмаг байж, эсвэл үнэхээр ойлгохгүй байж болохгүй; чи Миний өмнө ирж, Надтай байнга ярилцах ёстой.

Миний дотроос авсан юу ч бай, чамд хэрэгжүүлэх зам өгч, Миний хүч чадал чамайг дагаж, дэргэд чинь Би байх болно. Үргэлж Миний үгэн дотор яв, тэгвэл чи хорвоогийн бүх зүйлийг даван гарч, дахин амиллын хүчийг эзэмшинэ. Хэрвээ чиний үг, ааш авир, үйлдэлд Миний үг болон Би байхгүй бол, хэрвээ чи Надаас зайгаа барьж, өөрийнхөө дотор, оюун санааны үзэл, хоосон сургаал, дүрэм дунд амьдарвал оюун ухаанаа нүгэлд автуулсны чинь нотолгоо энэ юм. Өөрөөр хэлбэл, чи хуучин төрхтэйгээ зууралдаж, өөрт чинь жаахан ч гэлээ хор учруулж, сүнсийг чинь гэмтээхийг бусдад зөвшөөрдөггүй. Ийм хүмүүс туйлын тааруу хэв чанартай,

нэлээд этгээд бөгөөд Бурханы нигүүлслийг харж, Бурханы ерөөлийг таньж чаддаггүй. Хэрвээ чи цаашид булгсаар байвал, Намайг хэзээ өөрийнхөө дотор ажиллуулж чадах юм бэ? Намайг ярьж дуусахад чи сонслоо ч юу ч тогтоогоогүй байдаг бөгөөд асуудлууд чинь илэрхий болоход чи нэн сул дорой болдог. Ямар биеийн хэмжээ гэхээрээ ийм байдаг юм бэ! Хэрвээ чамайг үргэлж аргадах хэрэгтэй юм бол Би чамайг хэзээ бүрэн төгс болгож чадах юм бэ? Хэрвээ чи хавдаж, шалбарахаас айдаг юм бол бусдадаа “Би хэнийг ч өөртэйгөө харьцахыг зөвшөөрөхгүй, би өөрөө төрөлх хуучин зан чанараасаа ангижирч чадна” гэж анхааруулахаар яарсан чинь дээр. Тэгвэл хэн ч чамайг шүүмжилж эсвэл чамд хүрэхгүй бөгөөд чиний төлөө санаа тавих хүнгүйгээр хүссэн арга замдаа чөлөөтэй итгэж болно. Чи энэ маягаар Миний мөрийг дагаж чадна гэж үү? Намайг өөрийн чинь Бурхан, өөрийн чинь Эзэн гэдэгт итгэлтэй байна гэж хэлэх чинь хоосон үг. Хэрвээ чамд үнэхээр эргэлзээ үгүй бол эдгээр зүйл асуудал болохгүй, тэгээд чи үүнийг өөрт чинь ирсэн Бурханы хайр, Бурханы ерөөл гэж итгэх болно. Би Өөрийн хөвгүүддээ хандаж ярьдаг бөгөөд Миний үгийг талархал, магтаалаар угтан авах хэрэгтэй.

13-Р БҮЛЭГ

Одоогийн нөхцөл байдалдаа та нар би гэх үзлийг дэндүү баримталдаг ба дотор чинь ихэд ноцтой шашны саад байна. Чи сүнсээрээ үйлдэх боломжгүй, Ариун Сүнсний ажлыг ойлгож чаддаггүй бөгөөд шинэ гэрлийг голдог. Чи сохор учир өдрийн нарыг харж чаддаггүй, чи хүмүүсийг мэддэггүй, “эцэг, эхээ” хэзээ ч орхиж чаддаггүй, сүнслэг ялгаж ухаарах чадвар дутмаг, Ариун Сүнсний ажлыг таньж мэддэггүй, мөн Миний үгийг хэрхэн идэж, уух талаар чамд ямар ч ойлголт байдаггүй. Үүнийг бие даан хэрхэн идэж, уухаа мэддэггүй чинь асуудал юм. Ариун Сүнсний ажил өдөр өдрөөр гайхмаар хурдан урагшилж байна; өдөр бүр шинэ гэрэл, мөн шинэ, соргог зүйлс гарч байна. Гэвч чи ойлгодоггүй. Харин чи судалгаа хийх дуртай, юмыг хянуур авч үзэлгүйгээр хувийн сонирхлынхоо дурангаар харж, мэлрэн сонсдог. Чи сүнсэнд хичээнгүйлэн залбирдаггүй, бас Над руу харж, эсвэл Миний үгийг илүү их тунгаан боддог ч үгүй. Тиймээс, чамд байгаа бүх зүйл нь бичиг үсэг, дүрэм, сургаал л юм. Чи Миний үгийг хэрхэн идэж, уух талаар тодорхой ойлголттой байх ёстой бөгөөд Миний үгийг Миний өмнө илүү олон удаа авчрах ёстой.

Одоо үед хүмүүс өөрсдийгөө орхиж чаддаггүй; тэд үргэлж өөрсдийнхөө зөв гэж боддог. Тэд өөрсдийн жижигхэн ертөнцөд гацдаг ба зөв хүмүүс биш юм. Тэд буруу санаа, зорилготой бөгөөд эдгээр зүйлд бахь байдгаараа байвал гарцаагүй шүүгдэнэ, мөн ноцтой тохиолдолд тэднийг таягдан хаяна. Хүссэн ямар ч хүнтэй нөхөрлөх биш, Надтай байнгын нөхөрлөлөө хадгалахад илүү хүчин чармайлт гаргах ёстой. Нөхөрлөдөг хүмүүсийнхээ талаар ойлгож, амийн сүнслэг хэргийн талаар нөхөрлөх ёстой; тэгж байж л бусдыг амиар хангаж, тэдний дутагдлыг нөхөж

чадна. Тэдэнтэй сургамжилсан өнгө аясаар ярих хэрэггүй; энэ нь үндсээрээ буруу байр суурь юм. Нөхөрлөлд чи сүнслэг хэргийн талаар ойлголттой байх ёстой, чи мэргэн ухаан эзэмших ёстой бөгөөд хүмүүсийн зүрх сэтгэлд юу байгааг ойлгож чаддаг байх ёстой. Хэрвээ бусдад үйлчлэх гэж байгаа бол чи зөв хүн байх ёстой бөгөөд өөрт байгаа бүх зүйлээрээ нөхөрлөх ёстой.

Надтай нөхөрлөж, Надтай ойр дотно хэлэлцэж, бие даан идэж, ууж, Бурханд ойр байж чадах нь чамд одоо чухал зүйл юм. Чи сүнслэг хэргийг аль болох хурдан ойлгодог болох ёстой, мөн хүрээлэн буй орчноо болон эргэн тойронд чинь юу зохицуулагдсаныг тодорхой ухаарч чаддаг байх ёстой. Намайг юу болохыг чи ойлгох чадвартай юу? Дутуу зүйл дээрээ үндэслэж идэж уун, Миний үгээр амьдрах нь чухал! Миний гарыг тань, бүү гомдолло. Хэрвээ чи гомдоллож, зайлан одох аваас Бурханы нигүүлслийг хүлээж авах боломжоо алдаж магадгүй юм. Надад ойртохоос эхэл: Чамд юу дутаж байна, чи хэрхэн Надад ойртож, Миний зүрх сэтгэлийг ойлгох ёстой вэ? Хүмүүс өөрсдийгөө орхиж чаддаггүй учраас Надад ойртоход тэдэнд хэцүү байдаг. Тэдний зан чанар үргэлж тогтворгүй, байнга халуун, хүйтнээр үлээж байдаг бөгөөд энэ хүмүүс аятай байдлын амтыг жаахан авмагцаа их зантай, сэхүүн болдог. Зарим хүн хараахан сэрээгүй байна; хэлдэг зүйлийн чинь хэр их нь чиний юу гэдгийг агуулдаг вэ? Үүнээс хэр их нь өөрийгөө хамгаалсан, хэр их нь бусдыг дуурайсан, бас хэр их нь дүрэм дагасан байна вэ? Ариун Сүнсний ажлыг ухаарч, ойлгож чаддагүйн чинь шалтгаан бол Надад яаж ойртохоо мэддэггүйд байгаа юм. Гаднаа, чи би гэх үзэл болон оюун санааны үзэлдээ найдан аливааг үргэлж эргэцүүлж байна; чи өчүүхэн хуйвалдааныг нууцхан судалж, оролцдог бөгөөд үүнийгээ ил гаргаж ч чаддаггүй. Энэ нь, Ариун Сүнсний ажлыг үнэхээр ойлгодоггүйг чинь харуулдаг. Хэрвээ чи Бурханаас ямар нэгэн зүйл ирдэггүй гэж үнэхээр мэддэг юм бол яагаад үүний эсрэг зогсож, голохоос эмээдэг юм бэ? Хэр олон хүн Миний төлөө зогсож, ярьж чадах вэ? Бүстэй хүүхдэд байдаг зан чанарын хүч тэнхээнээс чамд өчүүхэн ч хэлтэрхий алга.

Одоо үед зохицуулагдсан бүх зүйл нь та нарыг амиа өсгөхөд сургах, та нарын сүнсийг нарийн мэдрэмжтэй, хурц болгох, мөн Бурханаас ямар зүйлс ирдгийг танин мэддэг болгохын тулд та нарын сүнслэг нүдийг нээх зорилготой юм. Бурханаас ирдэг зүйл чамайг чадамж болон ачаатай үйлчлэх, сүнсэндээ тууштай байх боломж өгдөг. Надаас ирдэггүй бүх зүйл хоосон; чамд юу ч өгдөггүй, чиний сүнсийг хоосруулж, итгэлийг алдуулж, чи Бид хоёрын хооронд зай завсар гарган чамайг өөрийн чинь оюун санаанд дөнгөлдөг. Сүнсэндээ амьдрах үедээ чи шашингүй ертөнц дэх бүх зүйлийг даван гарч чаддаг боловч оюун санаандаа амьдарна гэдэг нь Сатанд мэхлэгдэх явдал; энэ бол мухардал юм. Энэ одоо тун энгийн: Зүрх сэтгэлээсээ Над руу хар, сүнс чинь тэр даруй чадалтай болно. Чи хэрэгжүүлэх замтай болж, Би алхам бүрд чинь замчилна. Миний үг цаг үргэлж, бүх газар чамд илчлэгдэнэ. Хаана, хэзээ байх нь, эсвэл ямар тааламжгүй орчин байх нь хамаагүй, Би чамайг тод хардаг болгох бөгөөд хэрвээ чи зүрх сэтгэлээсээ Надад найдвал

Миний зүрх сэтгэл чамд илчлэгдэнэ; энэ маягаар чи урдах замаараа явах бөгөөд хэзээ ч замаа алдахгүй. Зарим хүн гадна талаасаа замаа мэдрэх гэж оролддог хэр нь хэзээ ч сүнсэн дотроосоо оролддоггүй. Тэд Ариун Сүнсний ажлыг хэзээд ухаарч чаддаггүй. Бусадтай нөхөрлөх үедээ, дагах замгүй, юу хийхээ мэддэггүй тэд улам л будилдаг. Энэ хүмүүс өөрсдийг нь юу шаналгадгийг мэддэггүй; тэд олон зүйл эзэмшдэг, дотроо сэтгэл хангалуун байдаг байж магад, гэхдээ энэ нь хэрэг болдог уу? Чамд дагах зам үнэхээр байна уу? Чи ямар нэгэн гэрэлтүүлэлт эсвэл гэгээрэл эзэмшсэн үү? Ямар нэгэн шинэ гүнзгий ойлголт чамд байна уу? Чи ахиц гаргасан уу, эсвэл ухарсан уу? Чи шинэ гэрэлтэй хөл нийлүүлж чадах уу? Чамд ямар ч дуулгавартай байдал байдаггүй; байнга дурддаг дуулгавартай байдал чинь ердөө л хоосон яриа. Чи дуулгавартай амийг амьдран харуулсан уу?

Хүмүүсийн өөрийгөө зөвтгөдөг, бардам, биеэ тоосон, сэхүүн, давлиун зангийн учруулдаг саад тотгор хэр том бэ? Бодит байдалд орж чадахгүй байхдаа чи хэнийг буруутгах вэ? Чи зөв хүн мөн эсэхээ мэдэхийн тулд өөрийгөө нарийвчлан шалгах хэрэгтэй. Сэдэл, зорилго чинь Миний төлөө байдаг уу? Чи бүх үг, үйлдлээ Миний өмнө хэлж, хийдэг үү? Би чиний бүх бодол, санааг шалгадаг. Чамд буруутай санагдахгүй байна уу? Чи бусдад үзүүлэх гэж хуурамч төрх гаргаад, тайван гэгч нь өөрийгөө зөвтгөх байдал гаргадаг; өөрийгөө халхавчлах гэж чи үүнийг хийдэг. Ёрын муугаа нуух гэж чи үүнийг хийдэг бөгөөд тэр ёрын муугаа өөр хүн рүү түлхэх арга замыг ч бодож олдог. Ямар ов мэх зүрх сэтгэлд чинь оршино вэ! Чи хэлсэн бүхнээ бод. Сүнсээ хор хөнөөлд өртүүлэхээс айж, Сатаныг нуусан, тэгээд ах, эгч нарынхаа идэж, уухыг хүчээр булаасан, тэр чинь өөрийнхөө эрх ашгийн тулд байсан биш гэж үү? Чамд өөрийгөө өмөөрч хэлэх зүйл байна уу? Энэ удаа Сатаны булаан авсан идэж, уух явдлыг чи дараагийн удаа цайруулж чадна гэж бодож байна уу? Тэгэхээр чи одоо үүнийг тодорхой харж байна; энэ чиний нөхөн төлж чадах зүйл үү? Чи алдагдсан цаг хугацааг нөхөж чадах уу? Өнгөрсөн хэдэн цуглаанд яагаад идэж, уухгүй байсныг, хэн энэ гай удсаныг мэдэхийн тулд та нар өөрсдийгөө хичээнгүйлэн шалгах ёстой. Үүнийг ойлгомжтой болтол нэг нэгээр нь нөхөрлөх ёстой. Хэрэв ийм хүнийг чанд хязгаарлахгүй бол ах, эгч нар чинь ойлгохгүй, тэгээд дахиад л тохиолдоно. Та нарын сүнслэг нүд аниастай байдаг; та нараас хэтэрхий олон нь сохор! Түүнээс гадна, хардаг хэд нь энэ талаар хааш яаш ханддаг. Тэд босож зогсоод чанга ярьдаггүй ба тэд ч бас сохор. Хардаг ч, чанга ярьдаггүй хүмүүс нь хэлгүй юм. Энд тахир дутуу олон хүн бий.

Зарим хүн үнэн гэж юу болох, амь гэж юу болох, зам гэж юу болохыг ухаж ойлгодоггүй, бас сүнсийг ойлгодоггүй. Тэд Миний үгийг томъёо төдий авч үздэг. Энэ нь хэтэрхий хөшүүн. Тэд чин сэтгэлийн талархал, магтаал гэж юу байдгийг ойлгодоггүй. Зарим хүн чухал, гол зүйлсийг ухаарч чаддаггүй; харин зөвхөн чухал бус зүйлсийг ухаардаг. Бурханы удирдлагад саад хийх гэдэг нь юу гэсэн үг вэ? Чуулганы барилгыг нураана гэдэг нь юу гэсэн үг вэ? Ариун Сүнсний ажилд саад хийх гэдэг нь юу гэсэн үг вэ? Сатаны зарц гэж юу вэ? Эдгээр үнэнийг зүгээр л

бөөрөнхийлж өнгөлөөд орхилгүй тодорхой ойлгох ёстой. Энэ удаа юунаас болж идэж, уусангүй вэ? Өнөөдөр Бурханыг чанга дуугаар магтах хэрэгтэй гэж зарим хүнд санагддаг, гэвч Түүнийг хэрхэн магтах ёстой вэ? Тэд магтан дуу дуулж, бүжиглэн магтах хэрэгтэй юу? Бусад арга хэлбэрүүд магтаалд тооцогддоггүй гэж үү? Зарим хүн, баяр хөөртэй магтаал бол Бурханыг магтах зам гэсэн үзэлтэйгээр цуглаанд ирдэг. Хүмүүс ийм үзэлтэй байдаг бөгөөд Ариун Сүнсний ажилд анхаарал тавьдаггүй; үүний эцсийн үр дүн гэвэл, саад гарсаар л байдаг. Энэ цуглаанаар идэж, уусангүй; та нар бүгд өөрсдийгөө Бурханы ачаанд санаа тавьдаг, чуулганы гэрчлэлийг хамгаална гэж хэлдэг боловч та нарын дундаас хэн чинь Бурханы ачаанд үнэхээр санаа тавьсан бэ? Өөрөөсөө ингэж асуу: Чи Түүний ачаанд санаа тавьсан хүн мөн үү? Чи Түүний төлөө зөвт байдлыг хэрэгжүүлж чадах уу? Миний төлөө зогсож, ярьж чадах уу? Үнэнийг тууштай хэрэгжүүлж чадах уу? Сатаны бүх үйл хэргийн эсрэг тэмцэх хангалттай зориг чамд бий юу? Чи сэтгэл хөдлөлөө хойш тавьж, Миний үнэний төлөө Сатаныг илчилж чадах уу? Миний санаа зорилгыг өөрийнхөө дотор гүйцэлдүүлж чадах уу? Эгзэгтэй мөчүүдэд чи зүрх сэтгэлээ өргөсөн үү? Чи Миний хүслийг биелүүлдэг хүн мөн үү? Эдгээр асуултыг өөрөөсөө асууж, байнга бод. Сатаны бэлэг чиний дотор байдаг бөгөөд хүмүүсийг ойлгож, Сатаны хорыг таньж чаддаггүй учраас чи үүнд буруутай; чи өөрийгөө үхэл рүү хөтөлж байна. Сатан чамайг будилж гүйцтэл чинь бүр мэхэлсэн байна; чи садар самууны дарсанд согтож, хатуу чанд үзэл бодол баримтлах чадваргүй хойш, урагш гуйвдаг бөгөөд чамд хэрэгжүүлэлтийн зам байхгүй. Чи зүй зохистой идэж, уудаггүй, галзуу зодоон хэрүүлд оролцож, зөвийг буруугаас ялгаж мэддэггүй бөгөөд удирдсан болгоныг дагадаг. Чамд ер нь ямар нэгэн үнэн байна уу? Зарим хүн өөрсдийгөө хамгаалж, бүр хууран мэхэлдэг. Тэд бусадтай нөхөрлөдөг боловч энэ нь тэднийг ердөө л мухардалд хүргэдэг. Энэ хүмүүс өөрсдийн санаа, зорилго, сэдэл, эх сурвалжийг Надаас олж авдаг уу? Идэх, уухыг нь булааж авснаа чи ах, эгч нартаа нөхөн төлж чадна гэж бодож байна уу? Нөхөрлөх цөөн хэдэн хүн олж, тэднээс асуу; өөрсдөөр нь яриул: Тэднийг аливаа зүйлээр хангасан уу? Эсвэл гэдэс нь бохир ус, хогоор дүүрч, тэд дагах замгүй үлдэж үү? Энэ чинь чуулганыг нураахгүй гэж үү? Ах, эгч нарын дундах хайр хаана байна вэ? Чи хэн нь зөв, хэн нь буруу гэж нууцаар судалдаг мөртлөө яагаад чуулганы төлөө ачаа үүрдэггүй билээ? Чи ердийн үед, ихэд дэлгэрсэн хэллэгүүдийг хашхирахдаа сайн боловч аливаа зүйл үнэхээр тохиолдоход эргэлздэг. Зарим хүн ойлгодог хэрнээ аяархан л бувтнадаг, харин бусад нь юу ойлгосноо чанга ярьдаг боловч өөр хэн ч үг хэлдэггүй. Тэд Бурханаас юу ирдгийг болон Сатаны ажил юу болохыг мэддэггүй. Амийн талаарх дотоод мэдрэмжүүд чинь хаана байна вэ? Чи зүгээр л Ариун Сүнсний ажлыг ухаардаг ч үгүй, таньж мэддэг ч үгүй бөгөөд шинэ зүйлсийг хүлээж авахад чамд хэцүү байдаг. Чи зөвхөн хүмүүсийн үзэлд нийцдэг шашны болон шашны бус зүйлсийг хүлээн зөвшөөрдөг. Үр дүнд нь чи зорилгогүйгээр тэмцдэг. Хэр олон хүн Ариун Сүнсний ажлыг ухаарч чаддаг вэ? Хэр олон хүн үнэхээр

чуулганы төлөө ачаа үүрсэн бэ? Чи үүнийг ухаардаг уу? Магтан дуу дуулах нь Бурханыг магтах нэг зам мөн боловч чи Бурханыг магтахын үнэнийг тодорхой ойлгодоггүй. Түүнээс гадна Түүнийг магтах зам чинь хатуу чанд байдаг. Энэ чинь чамд байдаг үзэл биш үү? Чи өөрийн үзэлтэй үргэлж нэгэн хэвийн зууралдаж, Ариун Сүнсний өнөөдөр хийх зүйлд анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй, ах, эгч нар чинь юу мэдэрч байгааг мэдэрч чаддаггүй, Бурханы хүслийг чимээгүйхэн эрж хайж чаддаггүй. Чи аливааг сохроор хийдэг; чи дуу сайн дуулж болох ч, үр дүн нь холион бантан болдог. Энэ үнэхээр идэж, ууж байгаа хэрэг үү? Үнэндээ хэн саад учруулж байгааг чи хардаг уу? Чи сүнсэнд огт амьдардаггүй; харин янз бүрийн үзлээс салдаггүй. Энэ чинь яаж чуулганы төлөө ачаа үүрэх зам байх юм бэ? Ариун Сүнсний ажил одоо бүр ч хурдан урагшилж байгааг та нар ойлгох ёстой. Тиймээс өөрийнхөө үзлээс тас зуурч, Ариун Сүнсний ажлыг эсэргүүцэж байгаа бол чи сохор биш гэж үү? Энэ нь ялаа хана мөргөн, дүнгэнэн эргэлдэхтэй адил биш гэж үү? Хэрвээ чи ийм маягаар цөхрөлтгүй үргэлжлүүлэх аваас хаягдах болно.

Гамшгийн өмнө бүрэн төгс болгуулсан хүмүүс Бурханд захирагддаг. Тэд Христээс хамааралтай амьдарч, Түүнд гэрчлэл хийж, Түүнийг өргөмжилдөг. Тэд бол ялгуусан бүстэй хүүхдүүд бөгөөд Христийн сайн цэргүүд юм. Өөрийгөө тайвшруулж, Бурханд ойртож, Түүнтэй нөхөрлөх нь одоо чухал. Хэрвээ Бурханд ойртож чадахгүй бол Сатанд олзлогдох эрсдэл чамд тулгарна. Хэрвээ Надад ойртож, Надтай нөхөрлөж чадвал бүх үнэн чамд илчлэгдэж, чи амьдарч, үйлдэх стандарттай болно. Чи Надад ойр нэгэн учраас Миний үг хажуугаас чинь хэзээ ч холдохгүй, амьдралынхаа турш Миний үгээс бас гажихгүй; Сатан чамайг ашиглах ямар ч аргагүй болох бөгөөд харин ч тэр шившиг болж, ялагдан зугтана. Хэрвээ дотроо дутагдаж байгаа зүйлийг гаднаас хайвал хааяа заримыг нь олж магадгүй боловч олсон зүйлийн чинь олонх нь дүрэм, журам болон чамд хэрэггүй зүйлс байх болно. Чи өөрийгөө орхиж, Миний үгийг илүү их идэж ууж, тэдгээрийг хэрхэн тунгаан бодохоо мэдэх ёстой. Ойлгохгүй зүйл гарвал Надад ойртож, Надтай байнга нөхөрлө; ийм маягаар, чиний ойлгодог зүйл бодит бөгөөд үнэн болно. Чи Надад ойр байхаас эхлэх ёстой. Энэ бол амин чухал! Эс тэгвээс, чи хэрхэн идэж уухаа мэдэхгүй. Чи өөрөө идэж ууж чаддаггүй; үнэндээ, чиний биеийн хэмжээ хэтэрхий жижиг.

14-Р БҮЛЭГ

Одоо цаг үнэхээр давчуу байна. Ариун Сүнс биднийг Бурханы үг рүү хөтлөхийн тулд олон өөр арга ашигладаг. Чи бүх үнэнээр зэвсэглэж, ариун болгуулж, Надтай үнэхээр ойр дотно, холбоотой байх ёстой; чамд сонголт үгүй. Ариун Сүнсний ажилд сэтгэл хөдлөл гэж үгүй бөгөөд чиний ямар хүн болохыг хайхардаггүй. Чи эрж хайж, дагахад бэлэн байгаа цагт—шалтаг тоочиж, өөрийн ашиг, алдагдлын талаар маргалгүй, зөвт байдлыг өлсөж, цанган хайвал чамайг Би гэгээрүүлнэ. Чи хэчнээн

мунхаг, тоомжиргүй байх нь хамаагүй, Би тийм зүйлсийг хардаггүй. Эерэг талд хэчнээн шаргуу хөдөлмөрлөж байгааг чинь Би хардаг. Би гэх үзэлтэйгээ зууралдаж, өөрийн бяцхан ертөнцөд эргэлдсээр байвал миний бодлоор чи аюулд оржээ… Өргөгдөх гэж юу вэ? Хаягдах гэж юу гэсэн үг вэ? Өнөөдөр чи Бурханы өмнө хэрхэн амьдрах хэрэгтэй вэ? Надтай чи хэрхэн идэвхтэй хамтран ажиллах хэрэгтэй вэ? Өөрийн үзлийг хаяж, өөрийгөө задлан шинжилж, багаа тайлж, үнэн төрхөө тодорхой харж, өөртөө зэвүүцэж, зөвт байдлыг өлсөж, цанган хайдаг зүрх сэтгэлтэй болж, өөрийнхөө юу ч биш гэдэгт итгэж, өөрийгөө орхиж, аливааг хийдэг бүх аргаа хаяж, Миний өмнө өөрийгөө тайван болгож, илүү их залбирч, Надад чин сэтгэлээсээ найдаж, Намайг хүндэлж, Надад ойртох, Надтай нөхөрлөхөө зогсоохгүй байх нь гол түлхүүр юм. Хүмүүс ихэвчлэн өөрсдийнхөөрөө байдаг ба Бурханы өмнө байдаггүй.

Ариун Сүнсний одоогийн ажлыг хүмүүс төсөөлөхөд үнэхээр хэцүү бөгөөд энэ нь бүгд бодит байдал руу ордог; бодлогогүй байж үнэхээр болохгүй. Хэрвээ зүрх сэтгэл, оюун ухаан чинь зөв биш бол, чи урагшлах замгүй болно. Эхнээсээ дуусах хүртлээ цаг ямагт сэрэмжтэй байж, цалгардлаас заавал сэргийлэх ёстой. Үргэлж сэрэмжтэй байж, хүлээдэг, Миний өмнө тайван байдаг хүмүүс ерөөлтэй ээ! Намайг байнга зүрх сэтгэлдээ хүндэлдэг, дуу хоолойг минь сайтар чагнахад анхаардаг, үйлдэлд минь анхаарал хандуулж, үгийг минь хэрэгжүүлдэг хүмүүс ерөөлтэй ээ! Хойшлуулах цаг үнэхээр алга байна. Та нарыг бүгдийг нь үер шиг залгихын тулд догшин, цуст амаа ангайн бүх төрлийн тахал тархах болно. Хөвгүүд минь! Цаг нь ирлээ! Тунгаан бодох цаг үлдсэнгүй. Миний хамгаалалтад та нарыг авчрах ганц гарц бол Миний өмнө эргэн ирэх явдал юм. Та нар эрэгтэй хүүхдийнх шиг хүчтэй зан авиртай байх ёстой, сул дорой байж, зүрх алдаж болохгүй; Миний алхамтай хөл нийлүүл, шинэ гэрлээс бүү татгалз, та нарт Миний үгийг яаж идэж уухыг чинь хэлэхэд дуулгавартай байж, зохих ёсоор идэж уух хэрэгтэй. Одоо нэг нэгэнтэйгээ зоргоороо арсалдаж, тэмцэлдэх цаг бас байна гэж үү? Цадталаа идэж, үнэнээр бүрэн зэвсэглээгүй бол дайн хийж чадах уу? Шашныг даван туулахыг хүсвэл үнэнээр бүрэн зэвсэглэсэн байх ёстой. Миний үгийг улам их идэж, уу, илүү их тунгаан бод. Чи Миний үгийг бие даан идэж ууж, Бурхантай ойртсоноор эхлэх ёстой. Үүнийг өөртөө анхааруулга болго! Чи анхаарал хандуулах ёстой! Ухаалаг хүмүүс үнэнийг хурдан сэхээрэх ёстой! Хагацахыг хүсдэггүй бүх зүйлээ хая. Эдгээр зүйл аминд чинь үнэхээр халтай, ямар ч ашиггүй гэдгийг Би чамд дахин хэлье. Би чамайг үйлдэлдээ Надад найдаж чадна гэж итгэж байна, эс тэгвэл өмнө чинь хүлээх цор ганц зам үхлийн зам байх болно, тэгвэл амийн замыг хайхын тулд чи хаачих билээ? Өнгөн талын зүйлстэй зууралдах дуртай зүрх сэтгэлээ тат! Бусад хүнд дуулгаваргүй байдаг зүрх сэтгэлээ тат! Хэрвээ амь чинь төлөвшиж чадалгүй, орхигдвол өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр гэдэг болох бус уу? Өнөөгийн Ариун Сүнсний ажил чиний төсөөлдөгтэй адилгүй. Хэрвээ чи өөрийн үзлийг хаяж чадахгүй бол их хохирол амсах болно. Хэрвээ энэ ажил хүний үзэлтэй нийцдэг байсан бол чиний хуучин уг чанар, үзэл ил болж чадна гэж үү? Чи өөрийгөө таньж

чадна гэж үү? Чи өөрийгөө ямар ч үзэлд баригдаагүй гэж бодсоор байж магадгүй ч, энэ удаад янз бүрийн үзэшгүй чанар чинь тодорхой илрэх болно. Өөрөөсөө анхааралтай ингэж асуу:

Чи Намайг дуулгавартай дагадаг хүн мөн үү?

Чи өөрийгөө хаяж, Намайг дагахыг хүсдэг үү, бас бэлэн үү?

Чи Миний төрхийг цэвэр ариун зүрх сэтгэлээр эрж хайдаг хүн мөн үү?

Чи Надад хэрхэн ойртож, Надтай хэрхэн нөхөрлөхөө мэдэх үү?

Чи Миний өмнө өөрийгөө тайван болгож, Миний хүслийг эрж хайж чадах уу?

Чи Миний илчилдэг үгийг хэрэгжүүлдэг үү?

Чи Миний өмнө хэвийн байдлаа хадгалж чадах уу?

Чи Сатаны зальхай явуулгыг нэвт харж чаддаг уу? Чи тэдгээрийг илчилж зүрхэлдэг үү?

Чи Бурханы ачааг хэрхэн анхаардаг вэ?

Чи Бурханы ачааг анхаардаг хүн мөн үү?

Чи Ариун Сүнсний ажлыг хэрхэн ойлгодог вэ?

Чи Бурханы гэр бүлд хэрхэн уялдаатай үйлчилдэг вэ?

Надад хэрхэн хүчирхэг гэрчлэл хийдэг вэ?

Үнэний төлөө хэрхэн сайн тэмцлээр тэмцдэг вэ?

Эдгээр үнэнийг сайтар тунгаан бодоход чи цаг гаргах ёстой. Тэр өдөр ойртож байгааг нотлох баримт хангалттай байна. Гамшгаас өмнө чи бүрэн төгс болгуулах ёстой—энэ бол үтэр түргэн шийдэх ёстой тун чухал асуудал! Би та нарыг бүрэн төгс болгох хүсэлтэй ч, та нар үнэхээр номхоршгүй мэт байна. Та нарт хичээл зүтгэл байгаа ч, тэрийгээ сайтар ашигладаггүй ба хамгийн чухал зүйлсийг ойлгохын оронд шалихгүй асуудлуудыг л ухаардаг. Эдгээр зүйлийг хэлэлцэх ямар хэрэг байна? Тэгэх нь цагийн гарз биш үү? Би та нарт ингэж нинжин сэтгэлээр ханддаг ч та нар талархахаа мэддэггүй, өөр хоорондоо л тэмцэлддэг, тэгэхээр Миний уйгагүй хичээл зүтгэл бүгд дэмий үрэгдээгүй гэж үү? Хэрвээ энэ маягаараа үргэлжлүүлбэл Би та нарыг ятгахад цаг гаргахгүй! Та нар үнэнийг ухаарахгүй бол Ариун Сүнсний ажлыг та нараас татаж авна гэдгээ хэлчихье! Та нарт дахиж идэх зүйл өгөхгүй, тэгээд та нар хүссэнээрээ итгэж болно. Өөрийн үгийг бүгдийг нь хэллээ, сонсоно уу, байна уу, та нар өөрсдөө мэд. Цаг нь ирэхэд та нар будилж, урагшлах замгүй, үнэний гэрлийг харж чадахгүй байх үедээ Намайг буруутгах уу? Яасан тоомжиргүй юм бэ! Өөртэйгөө салахгүй зууралдаж, тавьж явуулахаас татгалзвал үр дагавар нь ямар байх вэ? Ажил чинь хий хоосон хөдөлмөр болохгүй юу? Гамшиг тохиолдоход хөсөр хаягдвал хэчнээн хөөрхийлөлтэй билээ!

Одоо бол чуулганыг байгуулж байгаа чухал үе. Надтай санаачилгатайгаар хамтран ажиллаж, өөрийгөө Надад үнэн сэтгэлээсээ өргөн барьж, бүхнийг орхиж чадахгүй бол чи гарз хохирол амсана; чи өөр санаа зорилготой байж болох уу? Би та нарыг гэмшиж, шинээр эхлэхийг чинь хүлээж, энэ маягаар өршөөл үзүүлсэн. Гэхдээ цаг хугацаа үүнийг одоо үнэхээр зөвшөөрөхгүй бөгөөд Би том дүр зургийг

анхаарч үзэх ёстой. Бурханы удирдлагын төлөвлөгөөний зорилгын төлөө, бүх зүйл урагш ахиж, алхаа минь өдөр өдрөөр, цаг цагаар, хором хормоор урагш алхаж байгаа ба хөл нийлүүлж чадаагүй хүмүүс хаягдана. Өдөр бүр шинэ гэрэл гарч, өдөр бүр шинэ үйл хэрэг хийгдэж, өдөр бүр шинэ зүйл тохиолдож байхад гэрлийг харж чаддаггүй хүмүүс бол сохор юм! Дагадаггүй хүмүүс таягдан хаягдах болно…

15-Р БҮЛЭГ

Бурханы илрэлт аль хэдийн бүх чуулганд үзэгджээ. Үг хэлж байгаа нь Сүнс билээ, Тэр бол догшрох гал, Түүнд сүр жавхлан бий бөгөөд Тэр шүүж байна; Тэр бол хөлөө хүрсэн дээл өмсөж, цээжээрээ алтан бүс бүсэлсэн хүний Хүү билээ. Түүний толгой ба үс ноос адил цагаан, нүд нь галын дөл адил; хөл нь зууханд улайсгасан цэвэр хүрэл мэт; харин дуу хоолой нь их усны шуугиан мэт байдаг. Түүний баруун гарт долоон од, аманд нь хоёр талдаа иртэй хурц илд байх бөгөөд нүүр царай нь хурцаар гэрэлтэх нар мэт билээ!

Хүний Хүү гэрчлэгдэж, Бурхан Өөрөө ил тод илчлэгдлээ. Бурханы алдар гарч ирэн, аагим халуун нар мэт хурцаар гэрэлтжээ! Бурханы алдар суут нүүр царай нүд гялбам туяарна; хэний нүд Түүн рүү эсэргүүцэн харж зүрхлэх билээ? Эсэргүүцэл нь үхэл рүү хөтөлдөг! Чи зүрх сэтгэлдээ юу ч гэж бодсон, ямар ч үг хэлсэн, эсвэл юу ч хийсэн бай, өчүүхэн төдий ч өршөөл гэж үгүй. Миний шүүлтээс өөр олж авсан зүйлгүй гэдгийгээ та нар бүгд ойлгож, харах болно! Та нар Миний үгийг идэж, уух гэж хичээдэггүй хэр нь Миний бүтээн байгуулалтыг дур зоргоороо тасалдуулж, устгаж байхад Би тэвчээд өнгөрүүлж чадна гэж үү? Би тиймэрхүү хүнд зөөлөн хандахгүй! Зан авир чинь бүр ноцтой доройтвол чи галын дөлд залгиулна! Төгс хүчит Бурхан толгойноосоо өлмий хүртлээ мах, цусны өчүүхэн ч хэсэггүй сүнслэг биед биеллээ олдог. Тэрээр орчлон ертөнцөөс хэтийдэж, гуравдагч тэнгэрт алдар суут сэнтийдээ залран, бүх зүйлийг захирдаг! Орчлон ертөнц болон бүх зүйл Миний гарт бий. Би үг хэлбэл тэр нь биеллээ олно. Би тушаавал тэр ёсоор болно. Сатан Миний хөл дор, ёроолгүй нүхэнд байдаг! Миний дуу гарахад тэнгэр газар өнгөрөн одож, оргүй хоосон болно! Бүх зүйл шинэчлэгдэнэ, энэ бол туйлын зөв, хувиршгүй үнэн. Би дэлхийг бас бүх муу хүнийг ялан дийлсэн. Би энд суугаад та нартай ярьж байна; чихтэй бүхэн сонсогтун, амьтай бүхэн хүлээн авагтун.

Өдөр хоногууд төгсгөл болно; дэлхий дэх бүх зүйл оргүй хоосон болж, бүх зүйл шинээр төрнө. Үүнийг санагтун! Бүү март! Тэнд ямар ч ойлгомжгүй байдал байх ёсгүй! Тэнгэр газар өнгөрөн одно, гэхдээ Миний үг өнгөрөн одохгүй! Би та нарыг дахин нэг удаа ятгая: Дэмий бүү гүйлд! Сэрцгээ! Гэмшицгээ, аврал ойрхон байна! Би та нарын дунд хэдийн гарч ирж, Миний дуу хоолой сонсогдсон. Миний дуу хоолой та нарт дуулдаж, өдөр бүр та нартай нүүр нүүрээрээ учирдаг бөгөөд өдөр бүр шинэ сэргэг байдаг. Чи Намайг, Би чамайг харсан, Би чамтай байнга ярьдаг,

чамтай Би нүүр тулан байна. Гэсэн ч чи Намайг голдог, Намайг мэддэггүй. Миний хонь Миний дуу хоолойг сонсож чадна, гэсэн ч чи тээнэгэлзсээр байдаг! Чи тээнэгэлздэг! Зүрх сэтгэл чинь хатуурч, нүдийг чинь Сатан сохлоод, чи Миний алдар суут нүүр царайг харж чаддаггүй—хэчнээн өрөвдөлтэй вэ! Хэчнээн өрөвдөлтэй вэ!

Миний сэнтийн өмнөх долоон Сүнс дэлхийн өнцөг булан бүрд илгээгддэг ба чуулгануудад хандан яриулахаар Би Өөрийн Элчийг илгээнэ. Би бол зөвт агаад итгэмжит, хүний зүрх сэтгэлийн хамгийн гүнийг шинжилдэг Бурхан билээ. Ариун Сүнс чуулгануудад хандан айлдаж байгаа, энэ бол Миний Хүүгийн дотроос гардаг Миний үг юм; чихтэй бүхэн сонсох ёстой! Амьд бүхэн хүлээн авах ёстой! Тэдгээрийг зүгээр л идэж уу, бүү эргэлз. Миний үгийг дуулгавартай дагаж, анхаардаг бүх хүн асар их ерөөл хүртэнэ! Миний нүүр царайг чин сэтгэлээсээ эрж хайдаг бүх хүн гарцаагүй шинэ гэрэл, шинэ гэгээрэл, шинэ мэдлэг ухаантай болно; бүгд шинэлэг, шинэ байна. Миний үг хэдийд ч чамд үзэгдэж, сүнсний нүдийг чинь нээнэ, ийнхүү чи сүнсний ертөнцийн бүх нууцыг харж, хаанчлал хүмүүсийн дунд байгааг харж чадна. Хоргодох газарт ор, тэгвэл бүх нигүүлсэл болон ерөөл чам дээр ирж, өлсгөлөн тахал чамд хүрч чадахгүй, чоно, могой, бар, цоохор ирвэс ч чамд хөнөөл учруулж чадахгүй. Чи Надтай хамт явж, Надтай хамт алхаж, Надтай хамт алдар луу орно!

Төгс Хүчит Бурхан! Түүний алдар суут бие ил тод үзэгдэж, ариун сүнслэг бие гарч ирсэн, Тэр бол бүрэн төгс Бурхан Өөрөө мөн! Дэлхий ертөнц, бие махбод хоёулаа өөрчлөгдсөн бөгөөд уулан дээрх Түүний хувирал бол Бурханы үнэн бие билээ. Тэр толгойдоо алтан титэм зүүдэг, хувцас нь цав цагаан, цээжээрээ алтан бүстэй ба дэлхий ертөнц болон бүх зүйл Түүний хөлийн гишгүүр юм. Түүний нүд галын дөл адил, хоёр талдаа иртэй хурц илд аманд нь байдаг бөгөөд баруун гарт нь долоон од байдаг. Хаанчлалд хүрэх зам хязгаргүй гэгээлэг, Түүний алдар мандан гэрэлтэнэ; уулс баяр хөөртэй байж, ус инээн баясаж, нар сар, од эрхэс бүгд зохих зүй тогтлоороо эргэлдэж, ялгуусан эргэн ирэлтээрээ зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гүйцэлдсэнийг зарладаг цор ганц, жинхэнэ Бурханыг угтан авна. Бүгд баяр хөөртэйгөөр дэвхрэн бүжнэ! Хөөрөн баясацгаа! Төгс хүчит Бурхан алдар суут сэнтийдээ заларсан! Дуулцгаа! Төгс Хүчитийн ялгуусан туг далбаа сүр жавхлант, гайхамшигт Сион уулан дээр өндөрт мандлаа! Бүх үндэстэн уухайлж, бүх хүн дуулж, Сион уул баяр хөөртэйгөөр инээж байна, Бурханы алдар манджээ! Би зүүдэндээ ч Бурханы царайг харна гэж огт бодож байгаагүй, гэлээ ч өнөөдөр үүнийг харлаа. Би Түүнтэй өдөр бүр нүүр нүүрээ харан уулзаж, Түүнд зүрх сэтгэлээ нээдэг. Тэр идэж, уудаг бүхнээр харамгүй хангадаг. Амьдрал, үг, үйлдэл, бодол, санаа гээд бүгдийг Түүний алдар суут гэрэл гэрэлтүүлдэг. Тэр замын алхам бүрд хөтөлдөг, аливаа тэрслүү зүрх сэтгэл дээр шүүлт нь нэн даруй буудаг.

Бурхантай хамт идэж, хамт буудаллаж, хамт амьдарч, хамт байж, хамт алхаж, хамт баясаж, алдар, ерөөлийг хамт олж авч, Түүнтэй хамт хааны хэргэмийг хуваалцаж, хаанчлалд хамт оршино—өө, ямар таатай вэ! Өө ямар сайхан бэ! Өдөр

бүр нүүр нүүрээ харж, өдөр бүр Түүнтэй үг хэлэлцэж, байнга ярилцаж, өдөр бүр шинэ гэгээрэл, шинэ мэдлэг ухааныг хүртдэг. Бидний сүнслэг нүд нээгдэж, бүхнийг хардаг; сүнсний бүх нууц бидэнд илчлэгдсэн. Ариун амьдрал үнэхээр амарлингуй. Хурдан гүй, бүү зогс, үргэлж урагш тэмүүл, илүү гайхалтай амьдрал урд чинь байна. Чихэрлэг амтанд бүү цад, харин үргэлж Бурхан руу орохоор эрж хай. Тэр бүхнийг хамардаг, элбэг өгөөмөр бөгөөд бидэнд дутагддаг юм бүхэн Түүнд бий. Идэвх санаачилгатайгаар хамтран ажиллаж, Түүн рүү ор, цаашид юу ч урьдынх шигээ байхгүй. Бидний амьдрал ер бусын байх бөгөөд хэн ч, юу ч, ямар ч зүйл бидэнд саад болж чадахгүй.

Ер бусын! Ер бусын! Үнэхээр ер бусын! Бурханы ер бусын амь дотор орших ба бүх зүйл үнэхээр уужуу тайван болдог! Бид дэлхий ертөнц, ертөнцийн юмсаас хэтийдэж, нөхөр, хүүхдүүддээ сэтгэл хоргоддоггүй. Бид өвчин эмгэг, орчны хяналтыг даван гардаг. Сатан бидэнд саад болж зүрхэлдэггүй. Бүх гамшгаас бүрэн ангид болдог. Энэ бол Бурханд хаанчлах боломж олгож буй хэрэг! Бид Сатаныг хөл дооров гишгэлж, чуулганы төлөө гэрчлэлд зогсож, Сатаны муухай царайг бүрэн илчилдэг. Чуулганы бүтээн байгуулалт Христ дотор бий, алдар суут бие гарч ирлээ—энэ нь өргөгдсөн амьдрал билээ!

16-Р БҮЛЭГ

Хүний Хүүг гэрчилсний дараа, Төгс Хүчит Бурхан зөвт байдлын Нар болж Өөрийгөө бидэнд ил тодоор илчилсэн. Энэ бол уулан дээрх хувирал юм! Одоо энэ нь улам жинхэнэ, улам бодит байдал болж байна. Бид Ариун Сүнс хэрхэн ажилладгийг харсан, Бурхан Өөрөө махбодоос гарч ирсэн. Тэрээр хүн, орон зай, газар зүйн алины ч хяналтан дор байдаггүй; Тэр хуурай газар, далай тэнгисийн хилийг давж, бүхий л орчлон ертөнц даяар түгдэг бөгөөд бүх улс үндэстэн, бүх ард түмэн Түүний дуу хоолойг амьсгаа даран чагнаж байна. Сүнслэг нүдээ нээхдээ бид Бурханы үг алдар суутай биеэс нь гарсныг хардаг; энэ бол махбодоос гарч ирж буй Бурхан Өөрөө юм. Тэрээр бодит агаад бүрэн төгс Бурхан Өөрөө билээ. Тэд бидэнтэй ил тод ярьдаг, бидэнтэй нүүр нүүрээ харан уулзаж, бидэнд зөвлөж, биднийг өрөвдөж, биднийг хүлээж, биднийг тайтгаруулж, биднийг сахилгажуулж, бас шүүдэг. Тэр биднийг хөтлөн чиглүүлж, биднийг гэсэн анхаарал халамж нь Түүний дотор гал мэт дүрэлздэг; тэмүүлсэн зүрх сэтгэлээр Тэр биднийг сэрээж, Өөр лүүгээ оруулах гэж яардаг. Түүний ер бусын амь бид бүгдэд өгөгдсөн ба Түүн рүү орсон бүх хүн дэлхий ертөнц болон ёрын муу бүхнийг даван гарч, ялан дийлж, Түүнтэй хамт хаанчилна. Төгс Хүчит Бурхан бол Бурханы сүнслэг бие билээ. Хэрвээ Тэр зарлигдвал ёсоор болно; хэрвээ Тэр яривал гүйцэлдэнэ; хэрвээ Тэр тушаавал биелнэ. Тэр бол нэгэн жинхэнэ Бурхан! Сатан Түүний хөл дор, ёроолгүй нүхэнд байдаг. Орчлон ертөнц, бүх зүйл Түүний гарт бий; цаг нь ирлээ, бүх зүйл үгүй болж, шинээр төрөх болно.

17-Р БҮЛЭГ

Чуулган байгуулагдаж байгаа ба Сатан бүхий л чадлаараа үүнийг нураахаар оролдож байна. Тэрээр Миний барилга байгууламжийг байж болох бүх аргаар нураахыг хүсдэг, иймээс чуулганыг хурдан ариусгах ёстой. Ёрын муугийн өчүүхэн ч шавхруу үлдэх ёсгүй. Ямар ч өөгүй болтол нь, өнгөрсөнд байсны адил ариун хэвээр байх хүртэл нь чуулганыг ариусгах ёстой. Та нар цаг ямагт сэргэг байж, хүлээх ёстой бөгөөд Миний өмнө илүү их залбирах ёстой. Сатаны янз бүрийн явуулга, башир заль мэхийг олж харж, сүнсийг таньж мэдэн, хүмүүсийг мэдэж, бүх төрлийн хүмүүс, үйл явдал, юмсыг ялган таних чадвартай байх ёстой. Мөн Миний үгийг илүү их идэж, уух ёстой бөгөөд үүнээс ч чухал нь өөрсдөө идэж, ууж чаддаг байх ёстой. Бүх үнэнээр өөрсдийгөө зэвсэглэж, Миний өмнө ирэх аваас, Би та нарын сүнслэг нүдийг нээж, сүнсэн дотор орших бүхий л нууцыг та нарт харуулж болох юм… Чуулган байгуулагдах шатандаа орох үед ариун хүмүүс тулаанд ордог. Сатаны янз бүрийн үзэшгүй муухай шинж чанарыг та нарын өмнө тавьсан байдаг: Та нар болиод аажмаар ухрах уу, эсвэл босож зогсоод Надад түшиглээд үргэлжлүүлэн урагшлах уу? Сатаны ялзарсан, муухай шинж чанаруудыг гүйцэд илчилж, өрөвч сэтгэл бүү гарга, өршөөл бүү үзүүл! Сатантай үхтлээ тулалд! Би бол чиний ар тал, чамд хөвгүүний зан авир байх ёстой! Сатан үхэхийнхээ өмнө эцсийн удаа амь тэмцэн довтолж байгаа ч Миний шүүлтээс зугтаж бас л чадахгүй. Сатан Миний хөл дор байдаг, мөн та нарын хөл дор ч гишгэгддэг, энэ бол бодит баримт!

Тэр бүх шашны саад хийгчид болон чуулганы барилгыг нураагчдыг өчүүхэн ч тэвчиж болохгүй, харин нэн даруй шүүнэ; Сатан илчлэгдэж, гишгэлэгдэж, бүрэн устгагдаж, нуугдах газаргүй болно. Бүх төрлийн чөтгөр, сүг сүнснүүд Миний өмнө үнэн төрхөө гарцаагүй илчлэх бөгөөд Би бүгдийг нь хэзээ ч чөлөөлөгдөхгүй ёроолгүй нүхэнд хаяна; тэд бүгдээрээ бидний хөл дор байна. Хэрвээ үнэний төлөө сайн тэмцлээр тэмцэхийг хүсвэл юун түрүүнд Сатанд ажиллах боломж олгох ёсгүй, үүний тулд нэг санаатай байж, уялдаатай үйлчилж чаддаг байж, өөрийн гэсэн бүх үзэл, бодол, харах өнцөг болон аливааг хийдэг арга барилаасаа татгалзаж, Миний дотор зүрх сэтгэлээ тайван байлгаж, Ариун Сүнсний дуу хоолойд анхаарлаа төвлөрүүлж, Ариун Сүнсний ажлыг анхаарч, Бурханы үгийг нарийвчлан туулах хэрэгтэй. Миний хүслийг биелүүлнэ гэсэн нэг л санаа зорилготой байх ёстой. Үүнээс өөр санаа зорилго байх ёсгүй. Надад бүх зүрх сэтгэлээрээ найдаж, Миний үйлдлийг болон аливааг хийдэг арга замыг анхааралтай ажиглах ёстой бөгөөд огтоос хайхрамжгүй хандах ёсгүй. Сүнс чинь хурц, нүд чинь нээлттэй байх ёстой. Ерөнхийдөө, санаа болон зорилго нь зөв биш, бусдад харагдах дуртай, аливааг хийхдээ мэрийлттэй, саад боломтгой, шашны сургаал урсгахдаа сайн, Сатаны боол гэх мэт хүмүүсийн тухайд энэ хүмүүс босохоороо чуулганд бэрхшээл болдог бөгөөд ах, эгч нарынхаа Бурханы үгийг ууж, идэхийг талаар болгодог. Ийм хүмүүс жүжиглэж байвал, тэднийг нэн даруй хоригло. Удаа дараа сануулсан ч тэд

өөрчлөгдөхгүй бол хохирол амсана. Хэрвээ өөрсдийн замаар зөрүүдлэн зүтгэсээр байдаг хүмүүс өөрсдийгөө хамгаалахаар оролдож, нүглээ нуухаар завдвал чуулган тэднийг даруйхан тасдан хаяж, булталх газаргүй болгох хэрэгтэй. Ялихгүй юманд ямааны гарз бүү гарга, юмыг өргөн хүрээнд хар.

Сүнслэг нүдээ одоо нээж, чуулган доторх хэд хэдэн төрлийн хүмүүсийг ялган таньж чаддаг байх ёстой:

Ямар төрлийн хүмүүс сүнслэг хэрэг явдлыг ойлгож, сүнсийг мэддэг вэ?

Ямар төрлийн хүмүүс сүнслэг хэрэг явдлыг ойлгодоггүй вэ?

Ямар төрлийн хүмүүс муу ёрын сүнстэй байдаг вэ?

Ямар төрлийн хүмүүст Сатан ажилладаг вэ?

Ямар төрлийн хүмүүс саад боломтгой байдаг вэ?

Ямар төрлийн хүмүүст Ариун Сүнс ажилладаг вэ?

Ямар төрлийн хүмүүс Бурханы ачаанд хайхрамжтай байдаг вэ?

Ямар төрлийн хүмүүс Миний хүслийг биелүүлж чаддаг вэ?

Хэн Миний үнэнч гэрчлэгч вэ?

Өнөөдрийн хамгийн өндөр дээд үзэгдэл бол чуулгануудад Ариун Сүнсний авчирдаг гэгээрэл юм гэдгийг мэдэж ав. Эдгээр зүйлийн талаар бүү мунгина, харин ч яаралгүйгээр нэгд нэггүй ойлгож авах нь та нарын амийн ахиц дэвшилд туйлын чухал! Нүдний чинь яг өмнө байгаа эдгээр зүйлийг ойлгохгүй бол урдах замаараа алхаж чадахгүй болж, уруу татагдаж, олзлогдох аюулд байнга байх бөгөөд залгиулж ч магадгүй. Одоо хийх гол зүйл бол зүрх сэтгэлдээ Надад ойртож, Надтай илүү их ярилцах чадвартай болоход анхаарах явдал юм. Ийнхүү ойртож, ярилцсанаар дутагдаж байгаа, эсвэл эрж хайж байгаа зүйлээ чи өөртөө бүтэн болгоно. Чиний амь гарцаагүй хангагдаж, шинэ гэгээрэлтэй болно. Урьд нь хэчнээн мэдлэггүй байсныг чинь Би хэзээ ч хардаггүй, та нарын өнгөрсөн гэм бурууг ч оюун санаандаа удаан хадгалаагүй. Намайг хэрхэн хайрладгийг чинь Би хардаг: Намайг бусад бүх зүйлээс илүү хайрлаж чадах уу? Мэдлэггүй байдлаа хаяхын тулд буцан эргэж, Надад найдаж чадах эсэхийг чинь Би харъя. Зарим хүн Надтай тэрсэлдэж, Намайг илт эсэргүүцэж, бусдыг шүүдэг; тэд Миний үгийг мэддэггүй, Миний царай төрхийг олох магадлал бүр ч бага. Намайг чин сэтгэлээсээ хайдаг, зөвт байдлаар өлсөж, цангасан зүрх сэтгэлтэй, Миний өмнө байдаг бүх хүний хувьд, Би чамайг гэгээрүүлж, чамд илчилж, хоёр нүдээрээ Намайг харж, Миний хүслийг биечлэн ухаарах боломж олгоно; Миний зүрх сэтгэл гарцаагүй чамд илчлэгддэг болохоор чи ойлгож болох юм. Өөрийн үгийн дагуу чиний дотор гэгээрүүлсэн зүйлийг минь чи хэрэгжүүлэх ёстой, эс тэгвээс чи шүүгдэнэ. Миний хүслийг дагаваас чи замаа алдахгүй.

Миний үг рүү орохоор эрж хайдаг бүх хүний нигүүлсэл болон ерөөл хоёр дахин их болж, өдөр бүр шинэ гэгээрэл, мэдлэг ухаан олж авч, өдөр тутам Миний үгийг идэж, уухдаа шинэлэг мэдрэмжийг авна. Тэд үүнийг амаараа амтална: Хэчнээн амттай вэ!… Чи болгоомжтой байх ёстой, жаахан мэдлэг ухаан олж авч, амттаныг

амсчхаад сэтгэл ханах ёсгүй. Үргэлжлүүлэн эрж хайх нь чухал! Ариун Сүнсний ажил бол үнэхээр гайхалтай бөгөөд бодитой хэмээн зарим хүн боддог—энэ нь үнэндээ Төгс Хүчит Бурханы үнэн бие ил тод илчлэгдэж буй явдал бөгөөд илүү агуу тэмдэг, гайхамшгууд урд бий. Цаг үргэлж болгоомжтой, сэргэг бай, эх сурвалжаас харцаа салгалгүй, Миний өмнө тайван байж, хянуур байж, анхааралтай сонсон, Миний үгэнд итгэлтэй бай. Ойлгомжгүй байдал байж болохгүй; хэрвээ эргэлзэх л юм бол хаалганы цаана хаягдана гэж Би эмээж байна. Тодорхой үзэгдэлтэй, ул суурьтай байж, амийн энэ урсгалыг дагаж, хаашаа ч урссан ойрхон дага; өчүүхэн төдий ч эргэлзэх ёсгүй. Зүгээр л идэж, ууж, магтаал өргөж, ариун зүрх сэтгэлээр эрж хай, хэзээ ч бүү бууж өг. Ойлгохгүй юу ч байсан Миний өмнө авчирч, эргэлзэх сэтгэлгүй байхад анхаарваас үлэмж хохирол амсахаас зайлсхийж магадгүй. Хөл нийлүүл! Хөл нийлүүл! Ойр бай! Саад тотгороо зайлуул, садар самуун бүү бай! Урагшаа яв, үнэн сэтгэлээсээ эрэлхийл, бүү ухар. Цаг үргэлж зүрх сэтгэлээ өргөн барьж, ганц хормыг ч алдаж болохгүй. Ариун Сүнс үргэлж хийх шинэ ажилтай байдаг, өдөр бүр шинэ зүйл хийж, өдөр бүр шинэ гэгээрэлтэй байдаг; уулан дээрх хувирал, Бурханы ариун сүнслэг бие гарч ирлээ! Зөвт байдлын Нар гэрэл цацруулан, гялбаж, бүх үндэстэн, бүх хүн Таны алдар цуутай дүр төрхийг харлаа. Миний өмнө ирсэн бүх хүн дээр Миний гэрэл тусах болно. Миний үг бол чамайг урагш хөтөлж буй гэрэл юм. Та нар алхахдаа баруун, зүүн тийш хазайлгүй, харин Миний гэрэл дотор алхана, та нарын үйлдэл үр ашиггүй зүтгэл болохгүй. Чи Ариун Сүнсний ажлыг тодорхой харах ёстой бөгөөд Миний хүсэл тэр дотор бий. Бүх нууц далдлагддаг боловч аажмаар чамд илчлэгдэнэ. Миний үгийг үргэлж санаж, Надтай илүү их ярилцахаар Миний өмнө ир. Ариун Сүнсний ажил урагшилдаг. Миний мөрөөр алх; агуу гайхамшгууд урд бий бөгөөд нэг нэгээрээ чамд илчлэгдэнэ. Хянамгай байж, хүлээж, сэргэг байдаг хүмүүс л тэдгээрийг харна. Залхуурахгүй байхад анхаар. Бурханы удирдлагын төлөвлөгөө эцсийн шатандаа ирж байна; чуулганы байгуулалт амжилтад хүрч, ялагчдын тоо хэдийнээ тогтоогдож, ялгуусан хөвгүүд бий болж, Надтай хамт хаанчлалд орж, Надтай хамт хаанчилж, төмөр саваагаар бүх улс орныг захирч, алдар дотор хамтдаа байх болно!

18-Р БҮЛЭГ

Чуулган барих нь үнэхээр хялбар зүйл биш! Би үүнийг барихад бүхий л зүрх сэтгэлээ зориулсан ба Сатан үүнийг нураахын тулд чадах бүхнээ хийх болно. Хэрвээ чи барьж байгуулагдахыг хүсвэл үзэгдэлтэй хүн байх ёстой; чи Намайг түшиж тулан амьдарч, Христэд гэрчлэл хийж, Христийг өндөрт өргөж, Надад үнэнч байх ёстой. Шалтаг тоочих хэрэггүй, харин оронд нь ямар ч болзолгүйгээр дуулгавартай дага; чи аливаа шалгалтыг тэсэж тэвчин, Надаас ирдэг бүхнийг хүлээн авах ёстой. Ариун Сүнс чамайг хэрхэн удирдаж буйгаас үл шалтгаалан

Түүнийг дагах ёстой. Чи хурц гярхай сүнстэй, аливааг ялгаж салгах чадвартай байх ёстой. Чи хүмүүсийг ойлгож, тэднийг сохроор дагадаггүй байж, сүнслэг нүдээ хурц байлгаж, бүхий л зүйлсийн тухай мэдлэгийг нэгд нэгэнгүй эзэмших ёстой. Надтай ижилхэн оюун санаатай хүмүүс Намайг гэрчлэн зогсож, Сатаны эсрэг шийдвэрлэх тулаанд тулалдах ёстой. Чи барьж байгуулагдаж, мөн тулаанд тулалдах ёстой. Би та нарын дунд байдаг, Би та нарыг дэмждэг, Би бол та нарын хоргодох газар.

Хийх ёстой эхний зүйлс чинь өөрийгөө ариусгаж, өөрчлөгдсөн хүн болж, тогтвортой ааш авиртай байх явдал юм. Эргэн тойрон чинь сайн ч бай муу ч бай амьдралдаа чи Намайг түших ёстой бөгөөд гэртээ, эсвэл өөр ямар ч орчин нөхцөлд байсан, хэн нэгнээс, эсвэл аливаа хэрэг явдал, асуудлаас болж эргэлзэх ёсгүй. Түүнээс гадна чи бат зогсож, ердийнхөөрөө Христийг амьдран харуулж, Бурханыг Өөрийг нь харуулах ёстой. Чи хэвийн байдлаар ажил үүргээ хэрэгжүүлж, үүргээ биелүүлэх ёстой; үүнийг ганцхан удаа хийж болохгүй, харин урт хугацаанд үргэлжлүүлэх ёстой. Чи Миний зүрх сэтгэлийг өөрийн зүрх сэтгэл мэт авч үзэж, Миний санаа зорилго чиний бодол болж, нөхцөл байдлыг бүхэлд нь авч үзэж, Христийг өөрөөсөө цацруулж, бусадтай уялдан үйлчлэх ёстой. Чи Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлж, Ариун Сүнсний авралын арга барилд өөрийгөө зориулах ёстой. Өөрийгөө хоосолж, гэмгүй, нээлттэй хүн болох ёстой. Ах, эгч нартайгаа хэвийн нөхөрлөж, харилцаж, сүнсэн дэх аливаа зүйлийг хийх чадвартай байж, бие биеэ хайрлаж, тэдний давуу талаар сул талаа тэнцвэржүүлж, чуулган дотор босгон байгуулагдахаар хичээх ёстой. Тэгсэн цагт л чи үнэхээр хаанчлалаас хувь хүртэнэ.

19-Р БҮЛЭГ

Ариун Сүнсний ажил урагш үргэлжлэхийн хэрээр Бурхан биднийг дахин нэг удаа Ариун Сүнсний ажилладаг шинэ арга барил руу оруулсан. Үр дүнд нь, зарим хүн гарцаагүй Намайг буруу ойлгож, Надад гомдол гаргасан. Зарим нь Намайг эсэргүүцэж, Надад тэрсэлж, Намайг шинжсэн. Гэсэн ч Би та нарын гэмшил болон өөрчлөлтийг өршөөнгүйгээр хүлээсээр байдаг. Ариун Сүнсний ажлын арга барилын өөрчлөлт бол Бурхан Өөрөө ил тод харагдсан явдал юм. Миний үг өөрчлөгдөхгүй хэвээр үлдэнэ! Миний аварч байгаа хүн чи учраас Би чамайг замын хагаст хаяхыг огтхон ч хүсэхгүй. Гэвч та нарын дотор эргэлзээ байдаг ба гар хоосон буцахыг хүсдэг. Зарим чинь урагшлахаа больж, зарим нь зүгээр л ажиглан, хүлээдэг. Гэлээ ч зарим нь нөхцөл байдалд идэвхгүй хандаж, зарим нь ердөө л бусдыг дуурайдаг. Та нар зүрх сэтгэлээ үнэхээр хатуужуулжээ! Миний та нарт хэлсэн зүйлийг аваад чи бахархаж, сайрхдаг зүйлээ болгожээ. Үүнийг цааш нь дэнсэлж үз: Энэ бол өршөөл, шүүлтийн үг та нар дээр бууж байгаа төдий юм. Та нар үнэхээр тэрслүү гэдгийг Ариун Сүнс хараад шууд ярьж, задлан шинжилж эхэлдэг. Та нар айх ёстой. Болчимгүй үйлдэл бүү хий, яаран бүү хөдөл, нэрэлхүү, биеэ тоосон, зөрүүд бүү бай!

Чи Миний үгийг хэрэгжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлж, хаа ч явсан Миний үгийг амьдран харуул, тэгснээр Миний үг чамайг үнэхээр дотроос чинь өөрчилж, Миний зан чанар чамд байж болох юм. Ийм үр дүн л жинхэнэ билээ.

Чуулганыг байгуулахын тулд та нар тодорхой биеийн хэмжээтэй байж, бүх зүрх сэтгэлээрээ, зогсолтгүй эрж хайх ёстой. Түүнчлэн Ариун Сүнсний шатаалт болон цэвэрлэлтийг хүлээн зөвшөөрч, өөрчлөгдсөн хүн болох ёстой. Ийм нөхцөлд л чуулганыг байгуулж чадна. Ариун Сүнсний ажил, чуулганы бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд та нарыг одоо хөтөлсөн. Хэрвээ та нар урьдын адил ухаангүй бөгөөд хойрго аашилсаар байх аваас ямар ч найдваргүй. Та нар бүх үнэнээр зэвсэглэж, сүнслэг ялган таних чадвартай байж, Миний мэргэн ухааны дагуу төгс замаар алхах ёстой. Чуулганыг байгуулахын тулд, та нар өнгөцхөн дуурайлгүй, амийн сүнсэн дотор байх ёстой. Амийн өсөлтийн үйл явц бол та нарын босгон байгуулагдах тэр үйл явц юм. Гэвч авьяас билигт найддаг, сүнслэг хэрэг явдлыг ойлгох чадваргүй, бодит байдал дутдаг хүмүүс босгон байгуулагдаж чаддаггүй, мөн цаг үргэлж Надад ойр байж, Надтай ярилцах чадваргүй хүмүүс ч бас босгон байгуулагдаж чадахгүй гэдгийг анхаарч ав. Оюун санаагаа үзлээр дүүргэсэн, эсвэл хоосон сургаалаар амьдардаг хүмүүс босгон байгуулагдаж чадахгүй ба сэтгэл хөдлөлдөө хөтлөгддөг хүмүүс ч бас босгон байгуулагдаж чадахгүй. Бурхан чамд яаж хандах нь хамаагүй, чи Түүнд бүрмөсөн захирагдах ёстой; Эс тэгвээс, чи босгон байгуулагдаж чадахгүй. Өөрийгөө чухалчлах, өөрийгөө зөвтгөдөг байдал, бардамнал, сэтгэл хангалуун байдалдаа автсан, их зантай, гайхуулах дуртай хүмүүс босгон байгуулагдаж чадахгүй. Бусадтай зохицон үйлчилж чаддаггүй хүмүүс мөн л босгон байгуулагдаж чадахгүй бөгөөд сүнслэг ялган таних чадваргүй, өөрсдийг нь хөтөлж буй хэнийг ч сохроор дагадаг хүмүүс ч ижил. Түүнчлэн Миний санаа зорилгыг ойлгож чаддаггүй, хоцрогдсон нөхцөл байдалд амьдардаг хүмүүс босгон байгуулагдаж чадахгүй, шинэ гэрлийг дагахдаа хэтэрхий удаан, аливаа үзэгдлийг үндэс сууриа болгоогүй хүмүүс ч бас босгон байгуулагдаж чадахгүй.

Чуулганыг алгуурлалгүйгээр байгуулах ёстой ба энэ бол Миний хувьд хойшлуулшгүй анхаарах хэрэг явдал билээ. Чи эерэг зүйлд анхаарлаа төвлөрүүлэн эхэлж, бүх хүчээрээ өөрийгөө өргөн барьж бүтээн байгуулалтын урсгалд нэгдэх хэрэгтэй. Эс тэгвээс, гологдох болно. Орхих хэрэгтэй зүйлийг бүрэн орхиж, ууж, идэх хэрэгтэй зүйлийг зохих ёсоор ууж, идэх хэрэгтэй. Миний үгийн бодит байдлыг амьдран харуулж, өнгөцхөн, чухал биш хэрэг явдалд анхаарлаа төвлөрүүлэхээ болих хэрэгтэй. Өөрөөсөө ингэж асуу: Миний үгийг хэр их ойлгож авсан бэ? Үүнийг чи хэр их амьдран харуулдаг вэ? Чи саруул ухаанаа хадгалж, хөнгөн хуумгай зүйл хийхийг тэвчих хэрэгтэй. Эс тэгвээс, ийм зан байдал амийн өсөлтөд хүрэхэд тус болохгүй, харин ч өсөлтөд чинь хор хөнөөл учруулна. Чи үнэнийг ухаарч ойлгож, хэрхэн үүнийг хэрэгжүүлэх талаар мэдэж, Миний үгийг үнэхээр амиа болгох хэрэгтэй. Энэ бол хамгийн чухал зүйл юм!

Чуулганыг барьж байгуулах явдал одоо шийдвэрлэх мөчид ирэхийн хэрээр Сатан төлөвлөгөө боловсруулж, чуулганыг нураахаар чадах бүхнээ хийж байна. Та нар хайнга байх ёсгүй, харин ч болгоомжтой хөдөлж, сүнслэг ялган таних чадварыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Ийм ялган таних чадваргүйгээр, та нар үлэмж хохирол амсана. Энэ бол ялихгүй хэрэг явдал биш. Та нар үүнийг чухалчилж авч үзэх хэрэгтэй. Сатан ч бас хуурамч илрэлт үзүүлж, хуурамч зүйлсээр наймаацах чадвартай боловч эдгээр зүйлийн бодит чанар өөр байдаг. Хүмүүс үнэхээр мунхаг, болгоомжгүй бөгөөд ялгааг нь харж чаддаггүй. Тэд цаг үргэлж саруул ухаан, тайван байдлаа хадгалах чадваргүй гэдгийг энэ нь мөн харуулдаг. Та нарын зүрх сэтгэл хаа ч алга. Үйлчлэл бол нэг талаар нэр төр, нөгөө талаар хохирол байж болно. Энэ нь нэг бол ерөөл, эсвэл золгүй явдал руу хөтөлж болно. Миний өмнө тайван байж, Миний үгийн дагуу амьдар, тэгвэл чи үнэхээр сүнсээрээ сонор сэрэмжтэй байж ялган танина. Сатан ирэхэд, чи үтэр түргэн түүнээс сэргийлж, ирж байгааг нь мэдрэх чадвартай байх болно; чи сүнсэндээ жинхэнэ сэтгэлийн түгшүүрийг мэдэрнэ. Сатаны одоогийн ажил чиг хандлагын өөрчлөлтөд дасан зохицдог. Хүмүүс ухаангүй аяглаж, сэрэмж дутвал, олзлогдсон хэвээр байх болно. Чи цаг үргэлжид анхааралтай байж, сонор сэрэмжтэй байх ёстой. Өөрийн ашиг, алдагдалтай бүү зууралд, өөрийн тусын тулд бүү тооцоол; харин Миний хүслийг биелүүлэхээр эрж хай.

Аливаа зүйлс ижилхэн харагдах ч чанараараа ялгаатай байж болох юм. Тиймээс та нар хүмүүсийг ч, сүснүүдийг ч таних хэрэгтэй. Ялган таних чадвартай байж, сүнслэг саруул ухаанаа хадгалах хэрэгтэй. Сатаны хор гарч ирэхэд тэр дор нь таних чадвартай байх ёстой; тэрээр Бурханы шүүлтийн гэрлээс зугтаж чадахгүй. Та нар сүнсэн дэх Ариун Сүнсний дуу хоолойг сайн сонсоход илүү анхаарал тавих хэрэгтэй; бусдыг сохроор бүү дага, худал зүйлийг үнэн гэж бүү андуур. Удирдаж буй хүн бүрийг зүгээр бүү дага, чи үлэмж хохирол амсах вий. Энэ нь чамд ямар санагдаж байна? Та нар үр дагаврыг нь мэдрэв үү? Үйлчлэлд санаан зоргоор хөндлөнгөөс оролцож, өөрийн үзэл бодлыг үүнд оруулах ёсгүй, эс бөгөөс Би чамайг цохин унагана. Үүгээр ч зогсохгүй, хэрэв чи дуулгавартай байхаас татгалзаж, хүссэнээрээ ярьж, хийх аваас Би чамайг тастан хаях болно! Чуулган илүү олон хүнийг хүч гарган цуглуулах шаардлага байхгүй; Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг, үнэхээр Миний үгийн дагуу амьдардаг хүмүүсийг л чуулган хүсдэг. Чи өөрийн бодит нөхцөл байдлыг мэддэг байх ёстой. Ядуу хүмүүс өөрсдийгөө баян гэж бодох нь өөрсдийгөө хуурч байгаа явдал биш гэж үү? Чуулганыг байгуулахын тулд та нар Сүнсийг дагах ёстой. Сохроор үйлдэхээ бүү үргэлжлүүл, харин байрандаа байж, өөрийн гүйцэтгэх үүргийг биелүүл. Чи үүрэг ролиосоо гарах хэрэггүй; гүйцэтгэж чадах ямар ч үүрэг байсан биелүүлэхийн тулд чадах бүхнээ хийх хэрэгтэй, тэгсэн цагт Миний зүрх сэтгэл хангалуун болох болно. Та нар бүгд ижилхэн чиг үүрэгт үйлчилнэ гэсэн үг биш. Харин ч хүн бүр тус тусын үүргийг гүйцэтгэж, чуулган дахь бусад хүмүүстэй уялдуулан үйлчлэлээ зориулах ёстой. Чиний үйлчлэл аль ч зүг рүү хазайх ёсгүй.

20-Р БҮЛЭГ

Ариун Сүнсний ажил хурдацтай урагшилж, та нарыг цоо шинэ ертөнцөд авчирч байна. Өөрөөр хэлбэл, хаанчлалын амьдралын бодит байдал өмнө чинь гарч ирлээ. Ариун Сүнсний хэлсэн үг зүрх сэтгэлийн чинь доторх гүн бодлыг шууд илчилсэн бөгөөд та нарын өмнө дүр зураг ээлж дараалан үзэгдэж байгаа. Зөвт байдлын төлөө өлсөж, цангадаг, дуулгавартай байх санаа зорилготой бүх хүн гарцаагүй Сионд үлдэж, Шинэ Иерусалимд суурьшина; Тэд Надтай хамт байхдаа нэр хүнд болон алдар сууг олж авч, сайхан ерөөлүүдийг хуваалцах нь гарцаагүй. Та нарын сүнслэг нүд нээгдээгүй байгаа учраас хараахан үзээгүй байгаа сүнслэг ертөнцийн зарим нууц одоо бий. Бүх зүйл туйлын гайхалтай бөгөөд хүмүүсийн өмнө нь хэзээ ч бодож байгаагүй гайхамшгууд, ер бусын зүйлс, юмс аажмаар бий болно. Төгс хүчит Бурхан хамгийн агуу гайхамшгуудаа үзүүлнэ, ингэснээр орчлон ертөнц, газар дэлхийн зах хязгаар, бүх үндэстэн, бүх хүн тэдгээрийг нүдээрээ харж чадах бөгөөд Миний сүр жавхлан, зөвт байдал, төгс хүчин хаана оршдогийг мөн харж чадна. Тэр өдөр ойртсоор байна! Энэ бол туйлын эгзэгтэй шийдвэрлэх мөч: Та нар ухарч няцах уу, эсвэл хэзээ ч эргэж буцалгүйгээр эцэст нь хүртэл цөхрөлтгүй хичээх үү? Ямар ч хүн, юмс, зүйл рүү бүү хар, дэлхий ертөнц, эсвэл нөхөр, хүүхдүүд, амьдралын талаарх болгоомжлол руугаа бүү хар; зүгээр л Миний хайр, өршөөл рүү хар, та нарыг олж авахын тулд Би юу төлснийг, Миний юу болохыг хар. Чамд урам зориг өгөхөд эдгээр зүйл хангалттай.

Цаг маш ойрхон байгаа бөгөөд Миний хүсэл яаралтай биелэх ёстой. Миний нэрээр байгаа хүмүүсийг Би хаяхгүй; та бүгдийг алдар луу аваачих болно. Гэхдээ одоо харахнээ энэ бол шийдвэрлэх мөч юм; тэрхүү дараагийн алхмыг хийж чадахгүй хүн бүр үлдсэн амьдралынхаа туршид халаглаж, гэмших ч тэгж мэдрэхэд хэтэрхий хожимдсон байна. Одоо та нарын биеийн хэмжээг бодитой туршилтад оруулж, чуулганыг барьж болох эсэх, та нар бие биедээ дуулгавартай байж чадах эсэхийг хардаг. Энэ өнцгөөс харвал, дуулгавартай байдал чинь үнэндээ шилж, сонгосон зүйлдээ дуулгавартай байх явдал юм; хэдий чи нэг хүнд дуулгавартай байх чадвартай ч чамд өөр нэгэнд дуулгавартай байхад хэцүү байдаг. Хүний үзэлд найдаж байгаа үед чи үнэндээ дуулгавартай байх ямар ч аргагүй. Гэхдээ Бурханы бодол хүнийхээс үргэлж давдаг! Христ үхэх хүртлээ дуулгавартай байж, загалмай дээр нас барсан. Тэрээр ямарваа нөхцөл болзол, эсвэл шалтгааны талаар юу ч хэлээгүй; энэ нь Эцэгийнх нь хүсэл байсан учраас Тэр дуртайяа дуулгавартай дагасан. Чиний одоогийн дуулгавартай байдал дэндүү хязгаарлагдмал. Би та бүгдэд хэлье, дуулгавартай байдал гэдэг нь хүмүүсийг дуулгавартай дагах явдал биш; харин ч энэ нь Ариун Сүнсний ажлыг дуулгавартай дагаж, Бурханыг Өөрийг нь дуулгавартай дагана гэсэн үг юм. Миний үг та нарыг дотроос чинь шинэчилж, өөрчилж байгаа, эс бөгөөс хэн нь хэнд дуулгавартай байх билээ? Та нар бүгд бусад хүмүүст дуулгаваргүй хандддаг. Та

нар цаг гаргаж, дуулгавартай байдал гэж юу болох, дуулгавартай амийг хэрхэн амьдран харуулж болохыг бодож тунгаах ёстой. Миний өмнө улам их ирж, энэ асуудлыг нөхөрлөх ёстой, тэгээд аажмаар үүнийг ойлгож эхлэх ба эцэст нь өөрийн дотор байгаа үзэл, сонголтуудыг орхино. Аливааг хийдэг Миний энэ арга замыг бүрэн дүүрэн ойлгох нь хүмүүст хэцүү байдаг. Хүмүүс аль талаараа сайн, эсвэл чадвартай нь хамаагүй—Бурханы төгс хүчийг илчлэхийн тулд Би хамгийн мэдлэггүй, хамгийн шалихгүйг нь ашигладаг бөгөөд үүний зэрэгцээ хүний зарим үзэл, санал, сонголтыг өөрчилдөг. Бурханы үйл хэрэг маш гайхалтай; тэдгээрийг ойлгоход хүний ухааны чадвар хүрэхгүй!

Хэрэв чи Надад гэрчлэл хийдэг нэгэн болохыг үнэхээр л хүсдэг бол үнэнийг цэврээр, алдаа мадаггүйгээр хүлээн авах ёстой. Миний үгийг хэрэгжүүлэхэд илүү төвлөрч, амиа хурдан төлөвшүүлэхээр эрэлхийлэх ёстой. Үнэ цэнэгүй зүйлсийг бүү эрж хай; тэдгээр нь амийн өсөлтөд чинь ямар ч ашиг тус өгөхгүй. Амь чинь төлөвшсөн цагт л та нар барьж байгуулагдаж чадна; тэр үед л хаанчлалд хүргэгдэнэ—энэ бол маргаангүй. Би чамтай бас л дахиад жаахан яримаар байна; Би чамд ихийг өгсөн, гэхдээ чи хэр ихийг үнэхээр ойлгосон бэ? Миний хэлсэн зүйлсээс хэр их нь чиний амийн бодит байдал болсон бэ? Миний хэлсэн зүйлсээс хэр ихийг нь чи амьдран харуулж байна вэ? Үр ашиггүй хүчин чармайлт бүү гарга; эцэст нь чи хий хоосноос өөр юунд ч хүрэхгүй. Бусад хүмүүс бодит ашиг тусыг маш хялбархан хүртсэн; харин чи яасан бэ? Чи зэвсэглээгүй, зэвсэг үүрээгүй бол Сатаныг ялан дийлж чадах уу? Чи амьдралдаа Миний үгэнд илүү их найдах ёстой, учир нь тэдгээр нь биеэ хамгаалах хамгийн шилдэг зэвсэг. Үүнийг анхааралдаа ав: Миний үгийг өөрийн эзэмшил мэтээр бүү авч үз; хэрэв чи тэдгээрийг ойлгодоггүй, эрж хайдаггүй, тунгаан ойлгохоор оролддоггүй, эсвэл тэдгээрийн талаар Надтай хэлэлцдэггүй, харин оронд нь маадгар, өөртөө сэтгэл хангалуун байдаг бол хохирол амсана. Чи одоо үүнээс сургамж авч, өөрийгөө хойш тавин, дутагдлаа нөхөхийн тулд бусдын давуу талыг ашиглах хэрэгтэй; зүгээр л хүсэж байгаа болгоноо бүү хий. Цаг хугацаа хэнийг ч хүлээдэггүй. Ах эгч нарын чинь амь өдрөөс өдөрт өсөж байна, тэд бүгд өөрчлөлтийг мэдэрч, өдрөөс өдөрт шинэчлэгдэж байна. Ах эгч нарын чинь хүч өсөж байна, энэ бол сайн зүйл! Барианы шугам руу хар эрчээрээ гүй; хэн ч өөр нэгэнд санаа тавьж чадахгүй, зүгээр л Надтай хамтран ажиллахад зүгээр л бодит хүчин чармайлт гарга. Үзэгдэлтэй, урагшлах замтай, зориг нь мохоогүй, үргэлж урагш хардаг хүмүүс ямар ч эргэлзээгүйгээр ялалт байгуулах нь гарцаагүй. Энэ бол шийдвэрлэх мөч. Зориг мохохгүй, шантрахгүй бай. Чи бүх зүйл дээр урагшаа харж, эргэж буцахгүй байх ёстой, бүх зүйлийг золиослон, бүхий л ээдрээт байдлыг орхиж, бүх чадлаараа нэхэн хөө. Чамд ганц амьсгаа үлдсэн л байвал эцэст нь хүртэл шаргуу байх ёстой; зөвхөн ингэж байж л чи магтаал хүртэх эрхтэй болно.

21-Р БҮЛЭГ

Ариун Сүнсний ажил одоо та нарыг шинэ тэнгэр, шинэ газар луу авчирчээ. Бүх зүйл шинэчлэгдэж, бүх зүйл шинээр эхэлж, бүх зүйл Миний гарт байна! Хүмүүс үүнийг өөрсдийн үзлээр ойлгох чадваргүй байдаг, тэдний хувьд энэ нь утгагүй санагддаг боловч ажиллаж байгаа хүн нь Би бөгөөд Миний мэргэн ухаан үүнд бий. Тиймээс та нар бүхий л үзэл, санаа бодлоо орхиж, Бурханы үгийг дуулгавартайгаар идэж, уухад л анхаарах хэрэгтэй; юунд ч эргэлзэх хэрэггүй. Би ийм маягаар ажиллаж байгаа тул ариун хариуцлага үүрнэ. Үнэн хэрэгтээ хүмүүс тодорхой нэг байдалтай байх шаардлагагүй. Харин энд Бурхан гайхамшигтай зүйлсийг хийж, бүхнийг чадагч байдлаа харуулж байгаа юм. Хүмүүс Бурханы талаар л биш юм бол бусдаар онгирох хэрэггүй. Эс бөгөөс, чи хохирол амсана. Бурхан зүдэрсэн хүмүүсийг тоос шорооноос татан гаргадаг бөгөөд даруу хүн өндөрт гарах ёстой. Би орчлон ертөнцийн чуулганыг удирдаж, бүх үндэстэн, ард түмнийг захирахын тулд Өөрийн мэргэн ухааныг бүх хэлбэрээр ашиглана. Ингэснээр тэд бүгд Миний дотор байж, чуулганд харьяалагддаг та нар бүгдээрээ Надад захирагдах болно. Өмнө нь дуулгавартай байгаагүй хүмүүс одоо Миний өмнө дуулгавартай байж, нэг нэгэндээ захирагдаж, нэг нэгийгээ хүлцэн тэвчих ёстой. Та нар амиараа холбогдож, бие биеэ хайрлаж, өөрсдийн сул талыг нөхөхийн тулд бүгд бусдынхаа давуу талаас суралцаж, хамтран үйлчлэх ёстой. Ийм маягаар чуулганыг барих ба Сатанд завших боломж гаргахгүй. Тэр үед л Миний удирдлагын төлөвлөгөө бүтэлгүйтэхээргүй болох юм. Би та нарт өөр нэг зүйлийг энд сануулъя. Энэ, тэр хүний байгаа байдал, эсвэл гаргасан ийм, тийм үйлдлээс нь болж буруу ойлголттой болж, сүнслэг байдлаа доройтуулахыг өөртөө бүү зөвшөөр. Миний харж буйгаар энэ бол зохисгүй бөгөөд үнэ цэнгүй зүйл юм. Чиний итгэдэг Нэгэн, Бурхан биш гэж үү? Энэ бол хэн нэг хүн биш. Чиг үүрэг нь ижил биш. Нэг л бие байдаг. Дор бүрнээ үүргээ биелүүлж, дор бүрнээ өөрийн байрандаа чадлынхаа хэрээр хичээдэг, оч болгонд гэрлийн гялбаа байдаг, амийн төлөвшлийг эрж хайдаг. Тийнхүү Би сэтгэл хангалуун байх болно.

Та нар Миний өмнө амар тайван байхад л анхаарах ёстой. Надтай ойр дотно ярилцаж, ойлгохгүй зүйлээ илүү их эрж хайж, залбирч, Миний цагийг хүлээ. Бүх зүйлийг сүнслэгээр тод хар. Замаа алдахаас сэргийлэхийн тулд хуумгай үйлдэл бүү хий. Ийм маягаар л, Миний үгийг идэж ууж байгаагийн чинь үр жимс бодитоор гарна. Миний үгийг дандаа идэж уу, Миний хэлсэн зүйлийг тунгаан бод, Миний үгийг хэрэгжүүлэхэд анхаар, Миний үгийн бодит байдлыг амьдран харуул; энэ бол гол асуудал. Чуулганыг байгуулах үйл явц нь бас амийн өсөлтийн үйл явц юм. Хэрвээ амь чинь өсөхөө боливол чамайг бүтээн байгуулж болохгүй. Төрөлх байдал, махан бие, урам зориг, хувь нэмэр, хүчин чармайлтад л найддаг бол чи хэчнээн сайн хүн байсан ч бүтээн байгуулагдахгүй. Чи амийн үгэн дотор, Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт дотор амьдарч, бодит нөхцөл байдлаа мэдэж, өөрчлөгдсөн хүн болох ёстой. Чи сүнсэндээ адилхан мэдлэг ухаантай, шинэ гэгээрэлтэй байх ёстой бөгөөд

шинэ гэрэлтэй хөл нийлүүлж чаддаг байх ёстой. Чи Надад зогсолтгүй ойртож, Надтай ярилцаж, Миний үгийг өдөр тутмын амьдралынхаа үйлдлийн үндэс болгож, Миний үгэнд үндэслэн бүх төрлийн хүмүүс, үйл явдал, зүйлсийг зохих ёсоор зохицуулж, Миний үгийг өөрийнхөө стандарт болгож, амьдралын бүх үйл ажиллагаандаа Миний зан чанарыг амьдран харуулж чаддаг байх ёстой.

Хэрвээ чи Миний хүслийг ухаж ойлгож, үүнд санаа тавихыг хүсдэг бол Миний үгийг анхаарах ёстой. Аливааг хийхдээ бүү яарч сандар. Миний сайшаадаггүй бүхэн муугаар төгсгөнө. Миний сайшаасан зүйлд л ерөөл ирдэг. Би үг хэлбэл тэр нь биеллээ олно. Би тушаавал тэр бат орших болно. Намайг хилэгнүүлэхээс зайлсхийхийн тулд та нар Миний зөвшөөрөөгүй зүйлийг яавч хийх ёсгүй. Эс бөгөөс, тэр үед гэмшихэд хэтэрхий оройтсон байх болно.

22-Р БҮЛЭГ

Бурханд итгэх нь амархан хийх зүйл биш. Та нар яахаа мэдэхгүй, бүхнийг идээд, бүгд ямар сонирхолтой, ямар амттай юм бэ гэж боддог! Магтан сайшаасаар байдаг зарим хүн бий—тэдний сүнсэнд ялган таних чадвар ер байдаггүй. Энэ бол нэгд нэггүй дүгнэвээс зохилтой туршлага юм. Эцсийн өдрүүдэд бүх төрлийн сүнснүүд өөрсдийн үүргийг гүйцэтгэхээр гарч ирэн, Бурханы хүүхдүүдийн ахиц дэвшлийг илэрхий эсэргүүцэж, чуулганы бүтээн байгуулалтад санаатайгаар саад хийхэд оролцдог. Хэрэв та нар үүнийг хөнгөхнөөр хүлээн авч, Сатанд ажиллах боломж өгвөл тэрээр чуулганыг эмх замбараагүй болгож, хүмүүс сандарч, цөхрөх бөгөөд бүр цаашилбал хүмүүсийн үзэгдэл нь алга болно. Ингэвэл, олон жилийн турш уйгагүй төлсөн төлөөс маань юу ч биш болно.

Чуулганы бүтээн байгуулалтын цаг үе нь мөн Сатаны хамгийн улангассан байх үе юм. Сатан цөөн тооны хүнээр дамжуулан байнга саад, төвөг учруулдаг бөгөөд энэ хүмүүс нь Сатаны үүргийг хамгийн амархан гүйцэтгэж чадах сүнсийг мэддэггүй хүмүүс болон шинэ итгэгчид байдаг. Ихэнхдээ хүмүүс Ариун Сүнсний ажлыг ойлгодоггүй учраас өөрийн дураар, яг өөрийн аливааг хийдэг арга зам, үзлийн дагуу дур зоргоороо аягладаг. Дуугүй бай—чамайг хамгаалахын тулд үүнийг хэлж байна. Сайн сонсоод, дуулгавартай дага. Чуулган, нийгэм хоёр ялгаатай. Хүссэн зүйлээ, эсвэл бодсон болгоноо чи шууд хэлчхэж болохгүй. Энэ Бурханы гэр учраас энд тэгж болохгүй. Бурхан хүмүүсийн аливааг хийх арга замыг хүлээн зөвшөөрдөггүй. Чи Сүнсийг дагаж юмсыг хийх ёстой, Бурханы үгийг амьдран харуулах ёстой, тэгвэл бусад хүмүүс чамайг бишрэх болно. Чи Бурханд найдсанаар өөрийн доторх бүх хүндрэлийг юун түрүүнд шийдвэрлэх ёстой. Доройтсон зан чанараа төгсгөл болгож, нөхцөл байдлаа үнэхээр ойлгох чадвартай болж, хэрхэн аяглах ёстойгоо мэддэг бол; ойлгохгүй байгаа аливаа зүйлийнхээ талаар үргэлжлүүлэн нөхөрлө. Хүн өөрийгөө мэдэхгүй байна гэдэг хүлээн зөвшөөршгүй зүйл. Эхлээд өвчнөө илаарьшуул, тэгээд

Миний үгийг илүү ойр ойрхон идэж уун, тунгаан бодсоноор Миний үгэнд үндэслэн амьдарч, үйл хэргээ хий; чи гэртээ ч бай, өөр газар ч бай хамаагүй дотор чинь хүч чадлаа хэрэгжүүлэхийг Бурханд зөвшөөрөх хэрэгтэй. Махан бие хийгээд төрөлхийн чанараас татгалз. Бурханы үгийг үргэлж өөрийн дотор ноёрхуул. Амь чинь өөрчлөгдөхгүй байна гэж санаа зовох шаардлагагүй; зан чанар чинь асар их өөрчлөгдсөн болохыг чи цаг хугацаа өнгөрөхөд мэдэрч эхэлнэ. Өмнө нь чи анхаарлын төвд байхын хүслэн болж, хэнийг ч сонсдоггүй, хэрээс хэтэрсэн хүсэлтэй, өөрийгөө зөвтгөдөг, бардам байсан—чи эдгээр зан чанараас аажмаар ангижирна. Хэрэв чи эдгээрийг яг одоо хаяхыг хүсэж байгаа бол энэ боломжгүй! Учир нь хуучны чи бусдыг өөртөө хүргэхгүй, энэ зан чанар дотор чинь ийм л гүн бат суусан байгаа. Тиймээс чи өөрийн зүгээс хүчин чармайлт гаргаж, Ариун Сүнсний ажлыг эергээр, идэвхтэйгээр дуулгавартай дагаж, өөрийн хүслээр Бурхантай хамтран ажиллаж, Миний үгийг хэрэгжүүлэхэд бэлэн байх ёстой. Хэрэв чи нүгэл үйлдвэл Бурхан чамайг сахилгажуулна. Буцаж ирээд ойлгож эхэлбэл дотор чинь тэр дороо амар тайван болно. Хэрэв чи дур зоргоороо яривал нэн даруй дотроос чинь сахилгажуулна. Бурхан иймэрхүү зүйлийг таашаадаггүй гэдгийг хараад чи тэр даруй хийхээ боливол дотоод амар амгаланг мэдэрнэ. Амийн мэдрэмж гэж юу болох, амийн мэдрэмж дотор хэрхэн амьдрах талаар ойлгодоггүй зарим нэг шинэ итгэгчид байдаг. Заримдаа чи юу ч хэлээгүй хэр нь дотроо яагаад ийм тайван бус байна вэ гэж гайхдаг. Энэ үед бодол, оюун санаа чинь буруу байдаг. Заримдаа чамд өөрийн гэсэн сонголт, өөрийн гэсэн үзэл, санал байдаг; заримдаа чи бусдыг өөрөөсөө доогуур үздэг; заримдаа чи хувиа хичээсэн тооцоолол хийдэг бөгөөд залбирч, өөртөө дүн шинжилгээ хийдэггүй. Ийм учраас дотор чинь тайван бус санагддаг. Магадгүй чи асуудал юу болохыг мэдэж байгаа учраас шууд л Бурханы нэрийг зүрх сэтгэлдээ дуудаж, Бурханд ойртдог бол чи сэргэх болно. Зүрх сэтгэл чинь маш их хямарч, тайван бус болсон үед Бурхан ярихыг чинь зөвшөөрч байна гэж огт бодох ёсгүй. Шинэ итгэгчид энэ тал дээр Бурханыг дуулгавартай дагахад онцгойлон анхаарах ёстой. Бурхан хүний дотор амар амгалан, баяр хөөр, тодорхой, баттай мэдрэмжийг өгдөг. Ойлгодоггүй, эх захыг нь алдуулдаг, дур зоргоороо аягладаг хүмүүс байх нь олонтоо—энэ бүхэн нь бүгд саад болдог; үүнийг хичээнгүйлэн анхааралдаа ав. Хэрэв чи ингэх магадлалтай бол үүнээс сэргийлж “урьдчилан сэргийлэх эм” уух хэрэгтэй; эс бөгөөс чи саад учруулж, Бурхан чамайг цохих болно. Өөрийгөө бүү зөвтгө; бусдын давуу талыг авч, өөрийн дутагдлыг нөх, бусад хүн Бурханы үгээр хэрхэн амьдарч байгааг ажигла, тэдний амьдрал, үйлдэл, үг ярианаас жишээ авах зүйл байгаа эсэхийг хар. Хэрэв бусдыг өөрөөсөө доогуур гэж үздэг бол чи өөрийгөө зөвтгөдөг, ихэрхүү бөгөөд хэнд ч ач тус болдоггүй. Одоо хамгийн чухал нь амьдаа анхаарч, Миний үгийг илүү их идэж уун, Миний үгийг туулж, Миний үгийг мэдэж, Миний үгийг үнэхээр өөрийн амь болгох явдал юм—энэ бол гол зүйл. Бурханы үгээр амьдарч чадахгүй хүний амь нь боловсорч чадах уу? Үгүй, чадахгүй. Чи цаг үргэлжид Миний үгээр амьдарч, Миний үгийг насан туршдаа

баримтлах дүрэм журмаа болгох ёстой, ингэснээр энэ дүрмээр аливааг хийвэл Бурханыг баярлуулдаг, өөрөөр аяглавал Бурхан үзэн яддаг гэдгийг чи мэдрэх болно; ингэвэл чи аажимдаа зөв замаар алхаж эхэлнэ. Ямар зүйл Бурханаас гардаг, ямар зүйл Сатанаас гардаг болохыг чи ойлгох ёстой. Бурханаас гардаг зүйл нь чамд улам илүү тодорхой үзэгдэл өгч, Бурханд улам ойр болгодог; ах эгч нартайгаа чин сэтгэлийн хайрыг хуваалцаж, чи Бурханы ачаанд санаа тавих чадвартай болж, Бурханыг хайрлах сэтгэл чинь хэзээ ч багасахгүй. Алхах зам өмнө чинь байна. Сатанаас гарч ирдэг зүйлс үзэгдэл чинь алга болж, өмнө нь байсан бүхнээ алдахад чамайг хүргэдэг; чи Бурханаас холдож, ах эгч нараа гэсэн хайр чинь үгүй болж, үзэн ядах сэтгэлтэй болно. Чи цөхөрч, цаашид чуулганы амьдралаар амьдрах хүсэлгүй болох бөгөөд Бурханыг хайрлах зүрх сэтгэл чинь үгүй болдог. Энэ бол Сатаны ажил бөгөөд мөн ёрын муу сүнсний хийдэг ажлын үр дагавар юм.

Одоо үе бол шийдвэрлэх мөч. Та нар эцсийн ээлжээ хүртэл байрандаа зогсож, сайн мууг ялгахын тулд сүнсний нүдээ тунгалаг болгож, чуулганыг байгуулахын төлөө бүхий л хүчээ дайчлах ёстой. Сатаны зарц нар, шашны үймээн самуун, ёрын муу сүнсний ажлыг арилга. Чуулганыг ариусгаж, Миний хүслийг саадгүй хэрэгжүүл, гамшгийн өмнөх энэ маш бага хугацаанд Би та нарыг аль болох хурдан бүрэн төгс болгож, алдарт аваачна.

23-Р БҮЛЭГ

Миний дуу хоолойг сонссон бүх ах, эгч нарт: Та нар Миний хатуу шүүлтийн дуу хоолойг сонссон, дэндүү их зовлон туулсан. Гэхдээ та нар Миний ширүүн дуу хоолойн ард Миний санаа зорилго нуугддагийг мэдэх хэрэгтэй! Та нарыг аврах гэсэндээ Би сахилгажуулдаг. Хайртай хөвгүүдийнхээ төлөө Би та нарыг лавтай сахилгажуулж, засаж, удалгүй бүрэн төгс болгоно гэдгийг та нар мэдэх хэрэгтэй. Миний зүрх сэтгэл ихэд тэсэн ядаж байгаа ч та нар Миний зүрх сэтгэлийг ойлгодоггүй бөгөөд Миний үгийн дагуу үйлддэггүй. Өнөөдөр Миний үг та нар дээр ирж, Бурхан бол элэгсэг Бурхан гэдгийг бодитоор таниулдаг бөгөөд та нарт бүгдэд Бурханы чин хайрыг амсуулдаг. Гэхдээ дүр эсгэж байгаа цөөн тооны хүмүүс бас бий. Тэд бусдын уй гашууг харахаараа дуурайж, бас нүдэндээ нулимс мэлтэгнүүлнэ. Гаднаа Бурханд өртэй бөгөөд харамсдаг мэт харагддаг боловч дотроо Бурханыг жинхэнээсээ ойлгодоггүй, Түүний талаар эргэлздэг хүмүүс бас байдаг; тэд нар ердөө дүр үзүүлж байна. Би ийм хүмүүсийг хамгийн их жигшдэг! Эрт орой хэзээ нэгэн цагт энэ хүмүүс Миний хотоос тусгаарлагдана. Миний санаа зорилго гэвэл, Намайг халуун сэтгэлээр хүсдэг хүмүүсийг Би хүсдэг бөгөөд Намайг чин үнэнээр эрэлхийлдэг хүмүүс л Намайг баярлуулж чадна. Би тэдэнд гарцаагүй Өөрийн гараар тусалж, тэдэнд гай гамшиг яавч тохиолдуулахгүй. Бурханыг үнэхээр

хүсдэг хүмүүс Бурханы зүрх сэтгэлд хайхрамжтай байж, Миний хүслийг биелүүлэхэд бэлэн байна. Иймээс та нар бодит байдал руу удалгүй орж, Миний үгийг амиа болгон хүлээн зөвшөөрөх ёстой—энэ бол Миний хамгийн том ачаа билээ. Хэрвээ бүх чуулган болон ариун хүмүүс бодит байдал руу орж, бүгд Надтай шууд нөхөрлөж, Надтай нүүр тулан уулзаж чаддаг болж, үнэн ба зөвт байдлыг хэрэгжүүлбэл, зөвхөн тэр үед л тэд Миний хайртай хөвгүүд, Миний ихэд таалдаг хүмүүс болно. Энэ хүмүүст Би бүх агуу ерөөлийг хайрлана.

24-Р БҮЛЭГ

Цаг хугацаа улам бүр ойртож байна. Сэрцгээ! Бүх ариун хүмүүс ээ! Би та нарт хандан ярьж, сонсож буй бүхэн сэрнэ. Би бол та нарын энэ олон жилийн турш итгэж ирсэн Бурхан билээ. Өнөөдөр Би махбод болж, нүдний чинь өмнө гарч ирсэн бөгөөд Намайг үнэхээр хүсдэг, Миний төлөө ямар ч төлөөс төлөхөд бэлэн, Миний үгийг үнэхээр сонсдог, үнэнийг хэрэгжүүлэхэд бэлэн байгаа хүмүүсийг ийнхүү илчилдэг. Би бол төгс хүчит Бурхан учраас хүний бүх далд нууцыг харж чадна, мөн хэн Намайг үнэхээр хүсдэгийг мэднэ, хэн Намайг эсэргүүцдэгийг мэднэ; Би бүх зүйлийг ажигладаг.

Миний зүрх сэтгэлийн дагуу байж, Миний ачааг хайхарч чаддаг бүлэг хүмүүсийг Би одоо аль болох хурдан бий болгохыг хүсэж байна. Гэхдээ Би Өөрийн чуулганыг цэвэрлэж, ариусгахаас түдгэлзэж чадахгүй; чуулган бол Миний зүрх билээ. Миний үгийг идэж уухад чинь саад болдог бүх муу хүнийг Би жигшдэг. Учир нь Намайг үнэхээр хүсдэггүй цөөн хэдэн хүн бий. Энэ хүмүүс хууран мэхлэлтээр дүүрэн, чин сэтгэлээсээ Надад ойртдоггүй, мөн ёрын муу бөгөөд Миний хүслийг биелүүлэхэд саад болдог хүмүүс юм; тэд бол үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс биш. Энэ хүмүүс өөрийгөө зөвтгөдөг, биеэ тоосон зангаар дүүрэн, асар амбицтай, ихэрхүү байх дуртай бөгөөд ярьж байгаа үгийг нь сонсоход таатай ч нууцхандаа тэд үнэнийг хэрэгжүүлдэггүй. Энэ муу хүмүүс бүгд тусгаарлагдаж, устгагдан зайлуулагдана; тэд гамшигт зовж зүдэрнэ. Та нарт сануулж, сэрэмжлүүлэхийн тулд эдгээр үгийг хэлж байгаа бөгөөд ингэснээр та нар Миний зүрх сэтгэлийн дагуух замаар алхана. Үргэлж сүнс рүүгээ буцаж оч, учир нь Намайг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг хүмүүсийг Би хайрладаг. Та нар Надад ойртдог учраас Би та нарыг хамгаалж, энэ ёрын муу хүмүүсээс хол байлгаж, Өөрийн гэртээ бат зогсоож, эцсийг нь хүртэл та нарыг хамгаална.

25-Р БҮЛЭГ

Төгс Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон, бидний Бурхан бол хаан! Төгс Хүчит Бурхан хөлөө Чидун уулан дээр тавьжээ. Хэчнээн үзэсгэлэнтэй сайхан

бэ! Сонсоцгоо! Харуул бид дуу хоолойгоо өргөнө; хоолойгоо нэгтгэн бид хамтдаа дуулна, учир нь Бурхан Сионд эргэн ирлээ. Бид Иерусалимын эзгүйрлийг өөрсдийн нүдээр харж байна. Баярлан хөөрч, хоршин дуулцгаа, учир нь Бурхан бидэнд тайтгарал авчирч, Иерусалимыг золин аварсан билээ. Бурхан бүх үндэстний нүдэн дээр ариун мутраа ил болгож, Бурханы үнэн бие гарч ирлээ! Газар дэлхийн зах хязгаар бүр бидний Бурханы авралыг харлаа.

Өө, Төгс Хүчит Бурхан минь! Таны бүх нууцыг илчлэхээр долоон Сүнс Таны сэнтийгээс бүх чуулган руу илгээгдлээ. Та алдрын сэнтийдээ сууж, хаанчлалаа удирдаж, шударга ёс, үнэн зөвөөр түүнийгээ бат бөх, тогтвортой болгосон; Та бүх улс үндэстнийг Өөрийнхөө өмнө буулган авсан. Өө, Төгс Хүчит Бурхан минь! Та хаадын бүсийг суллаж, хотын хаалгыг Өөрийнхөө өмнө хэзээ ч хаагдахааргүй цэлийтэл нээсэн. Учир нь Таны гэрэл ирчихсэн, Таны алдар мандан, гэгээн гэрлээ цацруулж байна. Газар дэлхийг харанхуй нөмөрч, өтгөн харанхуй ард иргэдийг бүрхжээ. Өө, Бурхан минь! Гэхдээ Та илэрч, гэрлээ бидэн дээр тусгасан, Таны алдар бидэн дээр харагдах болно; бүх үндэстэн Таны гэрэлд, хаад Таны гялбаанд ирэх болно. Та нүд бэлчээн, эргэн тойрноо хардаг: Таны хөвгүүд өмнө тань цуглаж, хаа холоос ирдэг; Гарт нь Таны охид тэврүүлжээ. Өө, Төгс Хүчит Бурхан минь! Таны агуу хайр биднийг шүүрэн авсан; хаанчлалынхаа зам дээр Та биднийг дагуулан явж, Таны ариун үг бидэнд шингэдэг.

Өө, Төгс Хүчит Бурхан минь! Бид Танд талархаж, Таныг магтъя! Бид чин үнэнч, тайван, нэгэн зүрх сэтгэлээр Таныг биширч, Таныг гэрчилж, Таныг өргөмжилж, Танд дуулъя. Нэгэн санаа бодолтой байж, хамтдаа байгуулагдъя, удалгүй Та биднийг Таны зүрх сэтгэлийг эрэлхийлдэг, Танаар ашиглагддаг хүмүүс болгох болтугай. Таны хүсэл газар дэлхий дээр саадгүй биелээсэй гэж бид хүсэж байна.

26-Р БҮЛЭГ

Хөвгүүд минь, Миний үгийг анхаарч, Миний дуу хоолойг чимээгүй сонс, Би чамд илчлэл өгнө. Миний дотор чимээгүй бай, учир нь Би чиний Бурхан, та нарын цорын ганц Золин Аврагч. Та нар зүрх сэтгэлээ цаг үргэлж тайван байлгаж, Миний дотор амьдрах ёстой; Би чиний хад, та нарын тулгуур. Өөр санаа тээлгүй, үнэн сэтгэлээсээ Надад найд, Би та нарт мэдээж харагдана—Би та нарын Бурхан! Аа, тэр эргэлзэгчид! Тэд лав бат зогсож чадахгүй, юу ч олж авахгүй. Одоо ямар цаг үе гэдгийг, ямар чухал мөч гэдгийг та нар мэдэх ёстой! Хэчнээн чухал гээч! Хэрэггүй зүйлсээр бүү оролд; Надад түргэн ойртож ир, Надтай нөхөрлө, Би та нарт бүх нууцыг илчилнэ.

Та нар Ариун Сүнсний удирдамжийн үг бүрийг сонсож, бүгдийг нь үнэн сэтгэлээсээ авч үзэх ёстой. Та нар Миний үгийг маш олон удаа сонсоод дараа нь мартсан. Ай, бодолгүй хүмүүс ээ! Та нар маш их ерөөлийг алдсан! Одоо та нар

Миний үгийг хянуур сонсож, анхаар, Надтай илүү их нөхөрлөж, Надад улам ойрт. Ойлгодоггүй бүхэнд чинь Би чамайг залж чиглүүлж, та нарыг урагш хөтөлнө. Бусадтай илүү нөхөрлөх гэж бүү бод. Одоо бичиг үсэг, сургаал номлодог хүмүүс олон байдаг ба Миний бодит байдлыг жинхэнээсээ эзэмшдэг хүмүүс хэтэрхий цөөн. Тэдний нөхөрлөл хүнийг будлиулаад, хөшүүн, хэрхэн урагшлахаа мэдэхгүй болгодог. Тэднийг сонсоод хүн бичиг үсэг, сургаалын талаар арай жаахан ойлгодог болж магадгүй. Чи цаг ямагт анхааралтай алхаж, зүрх сэтгэлээ Миний өмнө амьдруулах ёстой; Надтай ярилцаж, Надад ойртож ирэх ёстой ба Би ойлгохгүй байгаа зүйлийг чинь харуулна. Чи хэл яриагаа цэнэж, зүрх сэтгэлээ цаг үргэлж ажиглаж, Миний алхдаг замаар алх.

Одоо удахгүй; бас жаахан цаг үлдсэн байна. Надаас бусад бүх зүйлийг хаяхаар яаравчил, ирээд Намайг дага! Би та нарт зохисгүй хандахгүй. Та нар Миний үйлдлүүдийг маш олон удаа буруу ойлгосон, гэтэл та нарт ямар их хайртайг минь чи мэдэх бил үү? Ай, та нар Миний зүрх сэтгэлийг ердөө ойлгодоггүй. Та нар Надад хэрхэн эргэлзсэн нь хамаагүй, Надад хэчнээн их өртэй байсан чинь ч хамаагүй, Би тэрийг чинь санахгүй, харин ч та нарыг урагшлуулж, Өөрийнхөө хүслийн дагуу үйлдүүлэхийн тулд Би та нарыг сонгосон.

Өнөөдөр назгайрах цаг биш. Хэрэв одоогоос өөр санаа зорилго тээх аваас Миний шүүлт та нар дээр бууна. Хэрвээ Намайг ганц хором ч атугай орхивол та нар Лотын эхнэр болно. Одоо Ариун Сүнсний ажил хурдасдаг бөгөөд шинэ гэрэлтэй хөл нийлүүлж чадахгүй хүмүүс аюулд өртөнө. Хянуур байдаггүй хүмүүс хаягдана; та нар өөрсдийгөө хамгаалах ёстой. Чамайг хүрээлэн буй орчны бүх зүйл Миний зөвшөөрлөөр оршдог, Би бүгдийг нь төлөвлөдөг гэдгийг чи мэднэ. Тодорхой харж, Миний чамд өгсөн орчинд Миний зүрх сэтгэлийг хангалуун байлга. Бүү ай, олон түмний Төгс Хүчит Бурхан чамтай гарцаагүй хамт байна; Тэр та нарын ард зогсдог, Тэр та нарын бамбай билээ. Өнөөдөр хүмүүст хэтэрхий олон үзэл байдаг болохоор Би арга буюу бусдад дорд үзэгддэг хүмүүсээр дамжуулан Өөрийнхөө хүслийг илэрхийлж, ихэрхүү, биеэ зөвтгөдөг, бардам, амбицтай, өндөр байр суурьтай хүмүүсийг ичээдэг. Миний ачаанд чин сэтгээлээсээ анхаарал хандуулж байгаа цагт Би та нарын төлөө бүхнийг бэлдэнэ. Зүгээр л Намайг дага!

27-Р БҮЛЭГ

Орчлон ертөнц болон бүх зүйлийг хаанчилдаг цорын ганц жинхэнэ Бурхан—эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурхан! Энэ бол Ариун Сүнсний гэрчлэл, няцаашгүй нотолгоо! Ариун Сүнс хаа сайгүй гэрчлэл хийхээр ажиллаж байгаа, ингэснээр хэн ч эргэлзэхгүй. Ялгуусан Хаан, Төгс Хүчит Бурхан! Тэрээр ертөнцийг даван дийлж, нүглийг даван дийлж, Өөрийн золин авралыг гүйцэлдүүлсэн! Мөн Сатаны ялзруулсан энэ бүлэг хүмүүс биднийг аварч, Өөрийн хүслийг биелүүлэхийн

тулд биднийг бүрэн төгс болгосон. Тэрээр бүх газар дэлхийд хаанчилж, энэ газрыг буцаан авч, Сатаныг ёроолгүй нүх рүү хөөдөг. Тэрээр дэлхий ертөнцийг шүүж байгаа бөгөөд Түүний гараас хэн ч зугтаж чадахгүй. Тэрээр Хаан болж хаанчилдаг.

Бүх газар дэлхий баярлан хашхирна! Ялгуусан Хаан, Төгс Хүчит Бурханы магтана! Үүрдийн үүрд! Та хүндлүүштэй, мөн магтууштай билээ. Орчлон ертөнцийн агуу Хаанд эрх мэдэл ба алдар суу нь байг!

Цаг хугацаа богинохон. Төгс Хүчит Бурханы мөрийг дагаж, үргэлжлүүлэн урагшил. Туйлын нягт нямбай байж, Түүний ачаанд анхаарал хандуулж, Түүнтэй санаа нэгтэй байж, удирдлагын төлөвлөгөөнийх нь төлөө өөрийгөө зарлагад. Чи өмч хөрөнгөө авч үлдэх ёсгүй, цаг их үлдээгүй. Тэднийгээ өргөл болго! Бүү хадгал! Өргөл болго! Бүү хадгал!

28-Р БҮЛЭГ

Цаг хугацаа маш түргэн өнгөрдөг бөгөөд Ариун Сүнсний ажил хурдан урагшилж, чамайг ийм агуу ерөөл хүртэн, ертөнцийн Хаан, гэрэлт Нар болох Төгс Хүчит Бурхан, хаанчлалын Хааныг хүлээн авахад хүргэснийг чи харж байна—энэ бүгд нь Миний нигүүлсэл болон өршөөл билээ. Чамайг Миний хайраас салгаж болох зүйл өөр юу байх билээ? Сайтар тунгаа, зугтах гэж бүү оролд, агшин тутамд Миний өмнө тайван хүлээ, битгий үргэлж гадуур сэлгүүц. Зүрх сэтгэл чинь Миний зүрх сэтгэлд ойрхон наалдах ёстой бөгөөд юу ч тохиолдож байсан ч аливааг сохроор, эсвэл дур зоргоороо бүү үйлд. Миний хүсэлд найдаж, Миний хүссэн болгоныг хийх ёстой ба Миний хүсээгүйг орхихоор сэтгэл шулуудсан байх ёстой. Чи сэтгэл хөдлөлдөө автан үйлдэж болохгүй, харин оронд нь эцэг, эхдээ ч хүртэл нялууралгүйгээр Миний нэгэн адил зөвт байдлыг хэрэгжүүл. Чи үнэнд нийцдэггүй бүхнийг хаяж, Надад өөрийгөө өргөж, Намайг хайрладаг ариун зүрх сэтгэлээр Миний төлөө зарцуух ёстой. Ямар нэг хүн, юмс болон зүйлийн хяналтад бүү зов; Миний хүсэлтэй нийцэж л байвал Миний үгийн дагуу хэрэгжүүл. Миний гар чамайг дэмждэг учир бүү ай, Би чамайг мууг үйлдэгч бүхнээс хол байлгана. Чиний амь Миний аминд түшиглэж амьдардаг учир чи зүрх сэтгэлээ хамгаалж, үргэлж Миний дотор байх хэрэгтэй; хэрвээ Намайг орхивол чи тэр дороо хатна.

Одоо бол эцсийн өдрүүд гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Диавол Сатан залгих хүмүүсээ хайж архирах арслан мэт гэтэж явдаг. Бүх төрлийн тахал одоо дэлгэрч, муу ёрын сүнсний бүх төрөл олноороо байна. Зөвхөн Би л жинхэнэ Бурхан; зөвхөн Би чиний хоргодох газар. Одоо зөвхөн Миний дотор, Миний нууц газарт нуугдахаас өөр чадах юм чамд үгүй бөгөөд аюул гамшиг тохиолдохгүй, ямар ч гай зовлон чиний майханд ойртохгүй. Чи Надад илүү олонтаа ойр ирж, Надтай нууц газар нөхөрлөх ёстой; бусад хүмүүстэй дур зоргоороо бүү нөхөрлө. Чи Миний үгийн утгыг ойлгох ёстой, Би чамайг нөхөрлөж болохгүй гэж хэлээгүй, гагцхүү чамд ялган таних

чадвар бас л алга. Энэ үед муу ёрын сүнснүүдийн ажил цадигаа алдаж байна. Тэд чамд нөхөрлөл өгөх гэж бүхий л төрлийн хүмүүсийг ашигладаг. Тэдний үг маш сайхан сонсогддог ч дотроо хор агуулдаг. Тэдгээр нь чихрээр бүрсэн сумнууд бөгөөд чамайг мэдэхээс өмнө дотор чинь хор суулгах болно. Өнөөгийн ихэнх хүмүүс согтуу мэт тогтворгүй гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Бэрхшээлийнхээ талаар бусадтай нөхөрлөхөд тэдний чамд хэлдэг зүйл нь ердөө дүрэм болон сургаал л байх болно, энэ нь Надтай шууд нөхөрлөж байгаа шиг адилхан сайн байдаггүй. Миний өмнө ирж, дотроо байгаа хуучин зүйлсийг бүрэн уудлан гарга; Надад зүрх сэтгэлээ нээ, Миний зүрх сэтгэл чамд гарцаагүй илчлэгдэнэ. Чиний зүрх сэтгэл Миний өмнө хичээнгүй байх ёстой. Бүү залхуур, харин Надад байнга ойртож ир— энэ бол амь чинь өсөх хамгийн дөт зам юм. Чи миний дотор амьдрах ёстой ба Би чиний дотор амьдарна, Би чиний дотор Хаан болж, бүх зүйл дээр чамайг чиглүүлэх бөгөөд чи хаанчлалын хувь хүртэнэ.

Өөрийгөө залуу гэж бүү чамла; чи Надад өөрийгөө өргөх хэрэгтэй. Би хүмүүсийн гадна үзэмж болон нас сүүдрийг хардаггүй. Би зөвхөн Намайг чин сэтгэлээсээ хайрладаг эсэхийг нь, мөн бусад бүх зүйлийг үл хайхран Миний замыг дагаж, үнэнийг хэрэгжүүлдэг эсэхийг нь л хардаг. Маргааш ямар байх, эсвэл ирээдүй ямар байх талаар санаа бүү зов. Өдөр бүр амьдрахдаа Надад түшиглэж байгаа цагт Би чамайг гарцаагүй хөтөлж заана. Сатаны илгээсэн “Миний амь хэтэрхий төлөвшөөгүй, би юу ч ойлгодоггүй” гэсэн бодолтой бүү зууралд. Надад байнга ойртохын тулд Миний мөрийг замын төгсгөл хүртэл дагахын тулд өөрийнхөө зүрх сэтгэлийг ашиглахад л болно. Чи Миний зэмлэл болон сэрэмжлүүлгийг сонсмогцоо сэрж, урагшаа гүй; Надад зогсолтгүй ойртож, сүргийн алхаатай хөл нийлүүлэн, чигээрээ тууштай яв. Миний дэргэд чи Бурханаа бүх зүрх сэтгэл, сүнсээрээ хайрлах ёстой. Үйлчлэх замдаа Миний үгийг илүү олонтаа тунгааж үз. Үнэнийг хэрэгжүүлэхдээ чи битгий халирхай бай, харин эрэгтэй хүүхдийн түс тас, шийдэмгий байдал бүхий хүчтэй зүрх сэтгэлтэй бай. Хэрвээ Намайг хайрламаар байвал, Би чамд гүйцэлдүүлэхийг хүсдэг бүх зүйл дээр чи Намайг хангалуун байлгах ёстой. Хэрвээ Намайг дагамаар байвал чи өөрт байгаа бүхнээ, хайрладаг бүхнээ хаях ёстой; Миний өмнө төлөв томоотой, даруухнаар, захирагдах ёстой. Бүү судалж шинжил, бүү замбараагүй бод, харин Ариун Сүнсний ажилтай үргэлж мөр зэрэгцэж яв.

Би чамд зөвлөгөө өгье: Чиний дотор гэгээрүүлсэн бүхнийг минь чанд хадгалж, заавал хэрэгжүүл!

29-Р БҮЛЭГ

Цаг давчуу байгааг чи мэдэх үү? Иймээс чи богино хугацаанд Надад найдаж, Миний зан чанартай нийцдэггүй мэдлэггүй байдал, удаан хариу үйлдэл, тодорхой

бус бодлууд, зөөлөн сэтгэл, дорой хүсэл, утгагүй явдал, хэт сэтгэл хөдлөл, төөрөгдөл, ялган таних чадвар дутмаг байдал зэрэг бүх зүйлээ өөрөөсөө таягдан хая. Эдгээрийг аль болох хурдан хаях ёстой. Би бол Төгс Хүчит Бурхан! Чи Надтай хамтран ажиллахыг хүсэж байгаа цагт бүх өвчнийг чинь Би эдгээж чадна. Би бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг Бурхан; чиний бүх өвчин эмгэгийг, мөн дутагдал чинь хаана оршдогийг Би мэддэг. Эдгээр нь амийн чинь ахиц дэвшилд саад болдог зүйлс бөгөөд тэдгээрийг даруйхан хаях ёстой. Эс бөгөөс Миний хүсэл чам дээр гүйцэлдэж чадахгүй. Чамд Миний гэрэлтүүлж өгдөг бүх зүйлийг хаяхын тулд чи Надад найдан, үргэлж Надаар амьдарч, Надтай ойр байж, үйл хөдлөл, зан авираа Миний төрхтэй байлга. Ойлгохгүй байгаа зүйлийнхээ талаар Надтай илүү их нөхөрлө, тэгвэл Би чамайг залж чиглүүлнэ, ингэснээр чи урагшилж болох юм. Хэрвээ чи ойлгохгүй байгаа бол дур зоргоороо бүү үйлд, харин Миний цагийг хүлээ. Тогтвортой зан авиртай байж, хүсэл тэмүүллээ нэгэн чигт байлга; чи үргэлж Намайг хүндэтгэдэг зүрх сэтгэлтэй байх ёстой. Миний өмнө, эсвэл Миний нүднээс далдуур чиний хийдэг зүйл үргэлж Миний хүслийн дагуу байх ёстой. Нөхөр чинь ч бай, эсвэл гэр бүл чинь ч бай, Миний өмнөөс хэнд ч бүү өршөөнгүй ханд; тэд хэчнээн сайн байсан ч ингэж болохгүй. Чи үнэнд үндэслэн үйлдэл хийх ёстой. Хэрвээ чи Намайг хайрладаг бол Би чамд агуу ерөөл хайрлана. Эсэргүүцдэг хэнийг ч Би тэвчихгүй. Миний хайрладаг хүмүүсийг хайрлаж, Миний үзэн яддаг хүмүүсийг үзэн яд. Хэнд ч, ямар ч үйл явдал, эсвэл ямар ч зүйлд анхаарал бүү хандуул. Миний ашигладаг хүмүүсийг сүнсээрээ тодорхой харж, сүнслэг хүмүүстэй илүү ойр ойрхон холбогд. Мэдлэггүй бүү бай; чи ялгаж салгах ёстой. Буудай үргэлж буудайгаараа л байх ба үрийн сүүл хэзээ ч буудай болж ургахгүй, чи өөр өөр төрлийн хүмүүсийг таних ёстой. Ялангуяа үг яриандаа хянамгай байж, Миний санаа зорилгын зам дээр хөлөө байлга. Эдгээр бүх үгийг анхааралтай тунгаан бодох ёстой. Чи тэрслүү байдлаа нэн даруй таягдан хаяж, Надаар ашиглуулахад тохирохуйц бол, ингэснээр чи Миний зүрх сэтгэлийг хангалуун болгоно.

30-Р БҮЛЭГ

Сэрцгээ, ах нар аа! Сэрцгээ, эгч нар аа! Миний өдөр хойшлогдохгүй; цаг хугацаа бол амь бөгөөд цаг хугацааг буцаан шүүрч авах нь амийг аварч байгаа хэрэг! Цаг тийм ч холгүй байна! Хэрэв та нар коллежийн элсэлтийн шалгалт өгөөд тэнцээгүй бол бэлдээд дахин хэдэн удаа ч хамаагүй өгч болно. Харин Миний өдөр цаашид саатаж тэвчихгүй. Санагтун! Санагтун! Эдгээр сайхан үгээр Би та нарыг яаруулж байна. Яг нүдний чинь өмнө дэлхийн төгсгөл илчлэгдэж, агуу гамшиг асар хурднаар ойртож байна. Юу илүү чухал вэ: амь чинь үү, эсвэл унтах, идэх, уух, өмсөж зүүх чинь үү? Эдгээр зүйлийг цэгнэх цаг чинь ирлээ. Ахиад битгий эргэлз, тодорхой байдлаас бүү зугт!

Ямар өрөвдөлтэй юм бэ! Ямар хөөрхийлөлтэй юм бэ! Ямар харалган юм бэ! Хүн төрөлхтөн ямар харгис юм бэ! Та нар үнэндээ Миний үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөдөг—Би та нартай дэмий ярьж байна уу? Яагаад хайхрамжгүй хандсаар байна вэ? Яагаад тэр вэ? Тийм бодол та нарт үнэхээр өмнө нь хэзээ ч төрж байгаагүй юу? Эдгээр зүйлийг Би хэний төлөө хэлдэг вэ? Надад итгэ! Би бол та нарын Аврагч! Би бол та нарын Төгс Хүчит Нэгэн! Сэрэмжтэй бай! Сэрэмжтэй бай! Алдсан цаг хугацаа дахин хэзээ ч ирэхгүй, үүнийг сана! Газар дэлхийн хаана ч харуусал намдаах эм байхгүй! Тэгвэл Би та нарт яаж хэлэх вэ? Миний үгийг анхааралтай бодож, дахин эргэцүүлвээс зохистой бус уу? Та нар Миний үгэнд маш хайхрамжгүй, аминдаа үнэхээр хариуцлагагүй ханддаг; Би үүнийг хэрхэн тэвчиж чадах билээ? Би яаж чадах билээ?

Энэ бүх хугацаанд та нарын дунд зөв зохистой чуулганы амьдрал яагаад бий болохгүй байна вэ? Учир нь та нарт итгэл дутагддаг, та нар төлөөс төлөхийг хүсдэггүй, өөрийгөө өргөн барихыг хүсдэггүй, Миний өмнө өөрсдийгөө зарлагадахыг хүсдэггүй. Сэрцгээ хөвгүүд минь! Надад итгэ, хөвгүүд минь! Хайрт хөвгүүд минь, Миний зүрх сэтгэлд юу байгааг яагаад бодолцож үзэхгүй гэж?

31-Р БҮЛЭГ

Намайг чин сэтгэлээсээ хүсдэг бүх хүнийг Би хайрладаг. Хэрвээ Намайг хайрлахад анхаарлаа төвлөрүүлбэл Би та нарыг цаглашгүй ихээр ерөөх нь гарцаагүй. Та нар Миний санаа зорилгыг ойлгож байна уу? Миний гэрт дээд доод байр суурийн ялгаа гэж үгүй. Хүн бүр Миний хүү бөгөөд Би бол та нарын Эцэг, та нарын Бурхан. Би цор ганц, дээдийн дээд. Би орчлон ертөнц болон бүх зүйлийг хянадаг!

Чи Миний гэрт “даруухнаар, үл анзаарагдах байдлаар Надад үйлчлэх” ёстой. Энэ үг чиний уриа болох хэрэгтэй. Модны навч биш, харин үндэс нь байж, амийн дотор гүн үндэслэ. Амийн жинхэнэ туршлага руу орж, Миний үгээр амьдарч, бүх зүйлээс Намайг эрж хай, Надад ойртож, Надтай нөхөрлө. Өнгөн талын ямар ч зүйлд бүү анхаарал хандуул, мөн ямар ч хүн, үйл явдал, зүйлд бүү хянуул, харин Би юу болох талаар сүнслэг хүмүүстэй л нөхөрлө. Миний санаа зорилгыг ойлгож, Миний амийг өөрсдийнхөө дунд урсгаж, Миний үгийг амьдран харуулж, Миний шаардлагад нийц.

Миний даалгасан асуудлуудад бүх хүчээ зориул; Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд бүх чадлаа зориул. Би бол чиний хүч чадал, чиний баяр хөөр … Би бол чиний бүх зүйл. Зүгээр л Намайг эрэлхийл. Би чиний зүрх сэтгэлийн чин хүслийг, Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддагийг чинь мэднэ, гэхдээ чи Миний гэрт Надад үнэнч гэдгээ хэрхэн харуулж, эцсээ хүртэл Намайг хэрхэн дагах вэ гэдгийг мэдэх ёстой.

Чуулган бол Миний зүрх сэтгэл, Би Өөрийн чуулганыг барихын төлөө түгшиж байна. Миний зүрх сэтгэлийг хангалуун болгохын тулд чи юу ч үлдээлгүйгээр өөрийгөө Миний төлөө зарлагадаж, Миний санаа зорилгод анхаарал хандуулах ёстой.

32-Р БҮЛЭГ

Гэрэл гэж юу вэ? Урьд нь та нар үнэн хэрэгтээ Ариун Сүнсний ажлын хувиралтыг гэрэл хэмээн хардаг байсан. Жинхэнэ гэрэл цаг үргэлжид байдаг: энэ нь, Надад ойртож, Надтай нөхөрлөснөөр Бурхан юу болохыг олж авах юм. Бурханы үгийг ойлгож, Түүний үгээс Бурханыг хүслийг ойлгох—өөрөөр хэлбэл, идэж, уухын сацуу Бурханы үгэнд Сүнсийг мэдэрч, Бурханы үгийг өөрсдийнхөө дотор хүлээж авах; туршлагаар дамжуулан Бурханы юу болохыг ухаарч, Бурхантай ярилцах зуураа Түүний гэрэлтүүлэлтийг хүлээн авах явдал юм; бүгд гэрэл юм. Эргэцүүлж, тунгаах зуураа чи хэдийд ч гэгээрүүлэгдэж, Бурханы үгээс шинэ мэдлэг ухаан олж авч чадна. Хэрвээ чи Бурханы үгийг ухаарч, шинэ гэрлийг мэдэрвэл үйлчлэлдээ хүч чадалгүй байх уу? Та нар үйлчлэл хийхдээ маш их санаа зовдог! Яагаад гэвэл та нар бодит байдалд хүрээгүй, та нарт жинхэнэ туршлага, эсвэл мэдлэг ухаан байдаггүй. Хэрвээ чамд жинхэнэ мэдлэг ухаан байсан бол чи хэрхэн үйлчлэхээ мэдэх байсан бус уу? Тодорхой зүйлс чамд тохиолдоход тэдгээрийг хичээнгүйлэн туулах ёстой. Хэрвээ чи хялбар бөгөөд тухтай орчинд Бурханы дүр төрхийн гэрэлд амьдарч чаддаг бол Бурханы царайг өдөр бүр харах болно. Хэрвээ чи Бурханы царайг харж, Бурхантай хэлэлцсэн бол чамд гэрэл байх бус уу? Та нар бодит байдалд ордоггүй, үргэлж гадна талд нь эрж хайсаар байдаг; үр дүнд нь та нар юу ч олдоггүй ба амийн ахиц дэвшил чинь удааширдаг.

Гадна талд анхаарлаа бүү төвлөрүүл; харин дотроо Бурхантай ойртож, гүн гүнзгий ярилцаж, Бурханы хүслийг ухаар; тэгвэл үйлчлэлдээ замтай байх бус уу? Та нар хичээнгүйлэн анхаарал тавьж, дуулгавартай дагах ёстой. Хэрвээ бүх зүйлийг зөвхөн Миний үгийн дагуу хийж, Миний заасан замд орвол замтай болохгүй гэж үү? Хэрвээ чи бодит байдалд орох замыг олбол Бурханд үйлчлэх замтай ч болно. Энэ бол энгийн! Бурханы өмнө улам их ирж, Бурханы үгийг илүү их тунгаа, тэгээд чи дутаж байгаа зүйлээ олж авна. Чи бас шинэ мэдлэг ухаан, шинэ гэгээрэл, шинэ гэрэлтэй байх болно.

33-Р БҮЛЭГ

Миний хаанчлалд үнэнч шударга, хоёр нүүргүй, ов мэхгүй хүмүүс хэрэгтэй. Гүдэсхэн, шударга хүмүүс энэ дэлхийд ад үзэгддэг бус уу? Би бол тэс ондоо. Үнэнч шударга хүмүүс Над дээр ирэхийг зөвшөөрнө; Би ийм хүнийг таашаадаг ба Надад

бас ийм хүн хэрэгтэй. Энэ бол чухамхүү Миний зөвт байдал юм. Зарим хүн мэдлэггүй; тэд Ариун Сүнсний ажлыг мэдэрч чаддаггүй, Миний хүслийг ойлгож чаддаггүй. Тэд гэр бүл болон эргэн тойрныхон нь оршдог орчныг тодорхой харж чаддаггүй ба аливааг сохроор хийж, нигүүлсэл хүртэх олон боломжийг алддаг. Тэд өөрсдийн үйлдэлд ахин дахин харамсдаг бөгөөд хэрэг явдалтай тулгарахдаа үүнийг дахиад л тодорхой харж чаддаггүй. Заримдаа арай ядан ялах гэж Бурханд түшиглэж чаддаг ч дараа нь ижил төрлийн хэрэг явдалтай тулгарвал хуучин өвчин нь сэдрээд, Миний хүслийг ухаарч чаддаггүй. Гэхдээ Би эдгээрийг хардаггүй бөгөөд та нарын гэм бурууг нэхэн санадаггүй. Харин ч Би та нарыг энэ садар самуун газраас аварч, амиа шинэчлэх боломж олгохыг хүсдэг. Би та нарыг ахин дахин өршөөсөн. Харин одоо үе бол хамгийн эгзэгтэй алхам. Та нар цаашид будилж болохгүй ба ингэж яваад, зогсоод байх маягаар урагшилж болохгүй. Хэзээ та нар хүрэх газраа очиж чадах юм бэ? Та нар бариа руу бүх чадлаараа, зогсолтгүй гүйх ёстой. Хамгийн чухал цаг үед идэвхээ бүү сулруул, зоригтой урагшил, элбэг дэлбэг найр өмнө чинь байна. Хуримын хувцас болон зөвт байдлын дээлээ хурдан өмсөөд Христийн хуримын зоогт оролц; гэр бүлийн аз жаргалыг мөнхөд эдэл! Чи урьдын адил сэтгэлээр унаж, гуниглаж, шүүрс алдахаа болино. Тэр үеийн бүх зүйл утаа мэт замхарсан байх бөгөөд Христийн дахин амилсан амь л чиний дотор ноёрхоно. Чиний дотор цэвэрлэгдэж, угаагдаад ариуссан сүм байх бөгөөд чиний олж авсан амилсан амь чамд үүрд мөнх оршино!

34-Р БҮЛЭГ

Төгс Хүчит Бурхан бол бүхнийг чадагч, бүхнийг гүйцэтгэгч, бүрэн төгс жинхэнэ Бурхан юм! Тэр долоон одыг атгаж, долоон Сүнсийг агуулан, долоон нүдтэй байж, долоон лац болон хуйлмал номыг нээгээд зогсохгүй, үүнээс ч илүүтэйгээр, Тэрээр долоон гамшиг, долоон аягыг удирдаж, долоон аянгыг илчилдэг. Тэр аль эрт долоон бүрээг мөн дуугаргасан! Түүний бүтээсэн, бүрэн төгс болгосон бүх зүйл Түүнийг магтаж, Түүнд алдрыг өгч, Түүний сэнтийг өргөмжлөх ёстой. Өө, Төгс Хүчит Бурхан минь! Та бол бүх зүйл. Та бүхнийг гүйцэлдүүлсэн ба Таныг байхад бүгд бүрэн төгс, гэгээтэй, сул задгай, эрх чөлөөтэй, бат бэх агаад хүчирхэг байдаг! Таныг байхад нуугдсан, далдлагдсан зүйл юу ч байдаггүй, бүх нууц илчлэгддэг. Түүнчлэн, Та үй олон дайснаа шүүж, Өөрийн сүр жавхланг илчлэн, Өөрийн догшин гал, уур хилэнг үзүүлсэнээс гадна урьд хожид үзэгдээгүй, үүрд мөнхийн, эцэс төгсгөлгүй алдар суугаа дэлгэн харуулсан! Бүх хүн сэрж, бүх чадлаараа уухайлан, дуулж, энэхүү төгс хүчит, бүхэлдээ-үнэн, бүхэлдээ-амьд, өгөөмөр, мөнхөөс мөнхөд орших суу алдарт, жинхэнэ Бурханыг шагшин магтах ёстой. Түүний сэнтийг үргэлж өргөмжлөн, Түүний ариун нэрийг магтаж, алдаршуулах хэрэгтэй. Энэ бол Миний—Бурханы—мөнхийн хүсэл бөгөөд Түүний бидэнд илчилж, хайрласан хязгааргүй

ерөөл юм! Бидний дундаас хэн үүнийг өвлөдөггүй вэ? Бурханы ерөөлийг өвлөхийн тулд Түүний ариун нэрийг өргөмжилж, сэнтийг нь тойрон шүтэн мөргөх ёстой. Түүний өмнө өөр сэдэл, өөр санаа зорилготой ирэх бүх хүн Түүний догшин галд хайлна. Өнөөдөр бол Түүний дайснуудын шүүгдэх мөн мөхөх өдөр. Түүнээс гадна, энэ өдөр бол Төгс Хүчит Бурхан Би илчлэгдэж, алдар суу болон нэр хүндийг олж авах өдөр юм. Өө, хүмүүс ээ! Бидэнд үүрдийн үүрд энэрэнгүй хайр илгээж, авралыг хэрэгжүүлэн, ерөөл хайрлаж, хөвгүүдээ бүрэн төгс болгон, хаанчлалаа амжилттай биелүүлдэг Төгс Хүчит Бурханыг магтаж, угтан авахаар хурдан босоцгоо! Энэ бол Бурханы гайхалтай үйл! Энэ бол Бурхан Өөрөө биднийг аварч, бүрэн төгс болгож, алдар суунд авчрахаар ирсэн Түүний мөнхийн урьдчилан тогтоолт, зохицуулалт юм.

Өндийн босож, гэрчлэл хийдэггүй хүмүүс бүгд сохрын өвөг дээдэс, мунхагийн хаад юм. Тэд мөнхийн үл тоогчид, үүрдийн тэнэгүүд бөгөөд үүрдийн сохор үхэгсэд болно. Иймд бидний сүнс сэрэх хэрэгтэй! Бүх хүн босох хэрэгтэй! Алдрын Хаан, өршөөлийн Эцэг, золин авралын Хүү, өгөөмөр долоон Сүнс, сүр жавхлант догшин гал, зөвт шүүлтийг авчирдаг, бүгдэд хүрэлцэхүйц, өгөөмөр, бүхнийг чадагч, бүрэн төгс Төгс Хүчит Бурханыг эцэс төгсгөлгүйгээр уухайлж, магтаж, өргөмжил! Түүний сэнтий үүрд өргөмжлөгдөнө! Энэ бол Бурханы мэргэн ухаан, Түүний авралын гайхамшигт зам, Түүний алдарт хүслийн биелэлт гэдгийг бүх хүн харах хэрэгтэй. Бид өндийн босож, гэрчлэл хийгээгүй байхад цаг нь нэгэнт өнгөрчихвөл, эргэж буцах зам гэж үгүй. Бидний ерөөл эсвэл, золгүй явдал хүртэх эсэх нь бидний яг одоо юу хийж, бодож, амьдран харуулж байгаа дээр үндэслэн аяллын маань одоогийн үе шатанд шийдэгдэж байгаа. Тэгвэл та нар хэрхэн аяглах хэрэгтэй вэ? Бурханыг үүрд гэрчилж, өргөмжилж, төгс хүчит Бурхан, эцсийн өдрүүдийн Христ—мөнхийн, цор ганц, жинхэнэ Бурханыг өргөмжил!

Одооноос та нар, Бурханд гэрчлэл хийдэггүй, цор ганц, жинхэнэ Бурханд гэрчлэл хийдэггүй, Түүний талаар эргэлзээ тээдэг хүмүүс бүгд өвчтэй, үхсэн бөгөөд Бурханыг эсэргүүцэгчид гэдгийг тодорхой харах хэрэгтэй! Бурханы үг эрт цаг үеэс хэдийнээ батлагдчихсан: Надтай хамт хуран цугладаггүй нь таран бутардаг, Надтай хамт байдаггүй нь Миний эсрэг байдаг; энэ бол чулуун дээр сийлсэн өөрчлөгдөшгүй үнэн! Бурханд гэрчлэл хийдэггүй хүмүүс бол Сатаны боолууд юм. Тийм хүмүүс Бурханы хүүхдүүдийг үймүүлж, хууран мэхэлж, Бурханы удирдлагад саад болохоор ирсэн; тэднийг хурц сэлмээр шийдвэрлэх ёстой! Тэдэнд сайхан сэтгэл гаргадаг хэн ч өөрсдийн сүйрлийг эрж хайж байдаг. Чи Бурханы Сүнсний айлдварыг сонсон, итгэж, Бурханы Сүнсний замаар алхаж, Бурханы Сүнсний үгээр амьдран харуулах хэрэгтэй. Түүнээс гадна төгс хүчит Бурханы сэнтийг цаг хугацааны төгсгөл хүртэл өргөмжлөх хэрэгтэй!

Төгс Хүчит Бурхан бол долоон Сүнсний Бурхан! Мөн Долоон нүд, долоон одны Бурхан, Тэр долоон лацыг нээдэг ба хуйлмал номыг бүхэлд нь дэлгэсэн! Тэрээр долоон бүрээг дуугаргасан бөгөөд долоон аяга, долоон гамшиг Түүний хүслээр буухад бэлэн атганд нь байдаг. Өө, үргэлж лацтай байсан долоон аянга минь!

Тэднийг илчлэх цаг нь ирлээ! Долоон аянгыг авчирах Нэгэн бидний нүдний өмнө хэдийнээ гараад ирчихсэн байна!

Төгс Хүчит Бурхан минь! Таныг байхад бүх зүйл сул задгай, эрх чөлөөтэй байж, хүндрэл бэрхшээл үгүй болоод бүгд төвөггүй урсдаг! Юу ч Танд саад болж зүрхэлдэггүй бөгөөд бүгд Танд захирагддаг. Захирагддаггүй хэн ч бай бүгд үхэх болно!

Төгс Хүчит Бурхан, Долоон нүдтэй Бурхан минь! Бүгд тов тодорхой, гэрэл гэгээтэй, нээлттэй бөгөөд бүгд илчлэгдэж, ил болсон. Түүнийг байхад бүгд болор шиг тунгалаг ба Бурхан Өөрөө ийм байгаад зогсохгүй, Түүний хөвгүүд ч бас ийм байдаг. Түүний болон Түүний хөвгүүдийн өмнө хэнийг ч, юуг ч, ямар ч хэргийг нуун далдалж чадахгүй!

Төгс Хүчит Бурханы долоон од тод гэрэлтэй! Чуулганыг Тэр төгс болгож, чуулганыхаа элч нарыг томилдог бөгөөд чуулган бүхэлдээ Түүний тэтгэмжинд байдаг. Тэр долоон лацыг бүгдийг нь нээж, Өөрийнхөө удирдлагын төлөвлөгөө болон хүслийг Өөрөө гүйцэлдүүлдэг. Хуйлмал ном бол Түүний удирдлагын нууцлаг сүнслэг хэл бөгөөд Тэр үүнийг дэлгэж, илчилсэн!

Бүх хүн Түүний цуурайтсан долоон бүрээг сонсох хэрэгтэй. Түүнийг байхад бүгд дахин нууцлалгүйгээр ил тод, нээлттэй болж, уйтгар гуниг байхгүй болдог. Бүгд илчлэгдэж, бүгд ялдаг!

Төгс Хүчит Бурханы долоон бүрээ бол нээлттэй, алдар суутай, ялгуусан бүрээнүүд юм! Тэдгээр нь мөн Түүний дайснуудыг шүүдэг бүрээ юм! Түүний ялалтын үеэр Түүний бүрээ мөн өргөмжлөгддөг! Тэр бүх орчлон ертөнцийг захирдаг!

Тэр гамшгийн долоон аягыг нэгэнтээ бэлдээд, дайснуудаа онилсон бөгөөд тэдгээрээ аадар бороо мэт цутгаж, дайснууд Түүний догшин галын дөлд автах болно. Төгс Хүчит Бурхан эрх мэдлийнхээ хүчийг үзүүлж, Түүний дайснууд бүгд устдаг. Эцсийн долоон аянга Төгс Хүчит Бурханы өмнө цаашид битүүмжлэгдэхгүй; бүгд илчлэгдсэн! Бүгд илчлэгдсэн! Тэр Өөрийн дайснуудыг долоон аянгаар үхэл рүү нь илгээж, газар дэлхийг тогтворжуулан, Түүнд үйлчлэл үзүүлж, дахин хэзээ ч дэмий үрэгдэхээргүй болгодог.

Зөвт Төгс Хүчит Бурхан минь! Бид Таныг үүрд шагшин магтъя! Та эцэс төгсгөлгүй магтаал, үүрдийн сайшаал болон өргөмжлөлийг хүртэх эрхтэй! Таны долоон аянга зөвхөн Таны шүүлтийн төлөө бус, харин Таны алдар суу, эрх мэдэл болон бүх зүйлийг бүрэн төгс болгохын төлөө байдаг!

Бүх хүн сэнтийн өмнө хөгжилдөж, Төгс хүчит Бурхан, эцсийн өдрүүдийн Христийг магтан шагшиж, өргөмжилдөг! Тэдний дуу хоолой орчлон ертөнцийг аянга мэт донсолгодог! Маргаангүй бүх зүйл Түүний улмаас оршиж, Түүний улмаас бий болдог. Бүх алдар суу, нэр хүнд, эрх мэдэл, мэргэн ухаан, ариун байдал, ялалт, илчлэлийг бүхэлд нь Түүнд хамаатуулахгүй байж хэн зүрхлэх билээ? Энэ бол Түүний хүслийн хэрэгжилт бөгөөд Түүний удирдлагын бүтээн босголтын эцсийн биелэлт юм!

35-Р БҮЛЭГ

Долоон аянга сэнтийгээс гарч, орчлонг чичрүүлж, тэнгэр газрыг орвонгоор нь эргүүлж, тэнгэрээр цуурайтна! Дуу нь чихэнд хадаж, хүмүүс үүнээс зугтаж ч, нуугдаж ч чадахгүй. Аянга, цахилгаан гялбаж, тэнгэр газар хоёр хоёулаа тэр даруй өөрчлөгдөж, хүмүүс үхлийн ирмэг дээр ирдэг. Дараа нь, догшин шуургатай аадар бороо гэрлийн хурдаар бүхэл сансар огторгуйг хамран тэнгэрээс бууна! Дэлхийн хамгийн алсын өнцөг буланд бүгдийг толгойноос хөл хүртэл шүршүүр шиг шалба цохиж ганц ч толбо үлдээхгүй; юу ч үүнээс нуугдаж, хэн ч үүнээс хоргодож чадахгүй. Аянгын нижигнээн, цахилгааны гялбаа шиг жихүүн цацраг хүмүүсийг айн чичрэхэд хүргэдэг! Хурц илд тэрслүү хөвгүүдийг цавчиж, орогнох газаргүй дайсан гамшигтай нүүр тулдаг; салхи, бороо дайрахад тэд балмагдаж, хүчинд нь өнхөрч, урсах усанд тэр дороо үхэтхийн унаж хөвөн одно. Зөвхөн үхэл байна, амьд үлдэх ямар ч арга тэдэнд байхгүй. Долоон аянга Надаас гардаг ба Египетийн ууган хөвгүүдийг устгаж, хорон мууг шийтгэж, Өөрийн чуулганууды цэвэрлэх санаа зорилгыг минь дамжуулдаг, ингэснээр бүгд өөр хоорондоо ойртож, хэлснээ үнэхээр хэрэгжүүлж, Надтай нэг зүрх сэтгэлтэй байж болох ба ингэснээр орчлон ертөнцийн бүх чуулган нэг болон барьж байгуулагдаж болно. Энэ бол Миний зорилго юм.

Аянга дуугарч, араас нь уйлах чимээ гардаг. Зарим нь нойрноосоо сэрж, ихэд түгшин, сүнсэндээ гүнзгий хайж, сэнтийн өмнө яаран буцдаг. Тэд эрээгүй хууран мэхлэлт, балмад үйлдлээ зогсоодог; ийм хүмүүсийн хувьд сэрэхэд нэг их оройтоогүй. Би сэнтийгээс хардаг. Би хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг. Намайг чин сэтгэлээсээ, гал цогтойгоор хүсдэг хүмүүсийг Би аварч, тэднийг өрөвддөг. Зүрх сэтгэлдээ өөр юунаас ч илүүгээр Намайг хайрладаг, Миний хүслийг ойлгодог, Намайг замын эцэс хүртэл дагадаг хүмүүсийг Би мөнхөд аварна. Миний гар тэднийг найдвартай барина, тэгснээр тэд энэ дүр зурагтай тулгарахгүй бөгөөд тэдэнд аюул учрахгүй. Зарим нь, цахилгааны энэ гялбааг хараад зүрх сэтгэлдээ хэлэхийн аргагүй зовж, жигтэйхэн их харамсдаг. Хэрвээ тэд ийм маягаар авирласан хэвээр байвал тэдний хувьд хэтэрхий оройтно. Ай, бүгд, бүх зүйл! Энэ бүгд дуусгавар болно. Энэ бас Миний авралын арга барилын нэг юм. Намайг хайрладаг хүмүүсийг Би аварч, өөдгүй мууг устгадаг, Өөрийн хаанчлалыг газар дээр бат, тогтвортой байлгаж, бүх улс үндэстэн, ард түмэн, бүх орчлон, дэлхийн зах хязгаарын бүгдэд Би бол сүр жавхлан, Би бол дүрэлзэх гал, Би бол хүн бүрийн зүрх сэтгэлийн гүнийг хайдаг Бурхан гэдгийг мэдүүлэх болно. Энэ цагаас эхлэн, агуу цагаан сэнтийн шүүлт олон нийтэд ил тод илчлэгдсэн ба шүүлт эхэлчихсэнийг бүх хүнд зарласан! Үг нь чин сэтгэлийн бус, эргэлздэг, итгэж зүрхэлдэггүй, Миний хүслийг ойлгодог ч хэрэгжүүлэх дургүй цаг дэмий үрэгсэд—бүгдээрээ шүүгдэх ёстой гэдэг нь эргэлзээгүй юм. Та нар өөрсдийн санаа зорилго, сэдлийг нарийвчлан шалгаж, зохих байр сууриа эзлэх ёстой; Миний үгийг буурьтай хэрэгжүүл, амийн туршлагадаа ач холбогдол өг, өнгөцхөн урам зоригтой бүү үйлд, харин өөрсдийн амийг өсгөж,

боловсруулж, баттай, туршлагатай болго—тэгсэн цагт л та нар Миний зүрх сэтгэлийн дагуу байх болно.

Сатаны зарц нарт болон Миний байгуулж байгааг үймүүлж, устгадаг муу ёрын сүнснүүдэд аливааг завших боломж бүү олго. Тэднийг чанд хязгаарлаж, хориглох ёстой; тэдэнтэй зөвхөн хурц сэлэм ашиглан харьцаж болно. Ирээдүйд төвөг учруулахаас сэргийлэхийн тулд хамгийн муу хүмүүсийг даруйхан үндсээр нь зайлуулах ёстой. Мөн чуулган төгс болж, бүх гаж байдал үгүй болох бөгөөд эрүүл саруул, эрч хүч, энергиэр дүүрэн болно. Гялбасан цахилгааны дараа, аянгын дуу нижигнэдэг. Чи хайнга байх ёсгүй, чи бууж өгөх ёсгүй, харин хөл нийлүүлэхийн тулд чадах бүхнээ хий, тэгээд Миний гар юу хийдгийг, Би юу олж авах гэдгийг, Би юу хаях гэдгийг, Би юу төгс болгох гэдгийг, Би юунаас ангижрах гэдгийг, Би юу устгана гэдгийг чи харж гарцаагүй чадна—энэ бүхэн та нарын нүдний өмнө дэлгэгдэн Миний бүхнийг чадагч хүчийг та нарт тодорхой харуулах юм.

Сэнтийгээс эхлээд орчлон ба дэлхийн зах хязгаарыг хүртэл долоон аянга цуурайтдаг. Бөөн хүн аврагдаж, Миний сэнтийн өмнө захирагдах болно. Амийн энэ гэрлийг дагаад хүмүүс амьд гарах зам эрж хайх бөгөөд Миний өмнө ирж, шүтэн мөргөхөөр сөгдөж, ам нь төгс хүчит жинхэнэ Бурханы нэрийг дуудаж, царайчлан гуйхаас өөр яаж ч чаддаггүй. Харин Намайг эсэргүүцдэг, хатуу сэтгэлтэй хүмүүсийн чихэнд аянга нүргэлэх ба тэд мөхөх ёстой нь эргэлзээгүй. Тэднийг ердөө л ийм эцсийн үр дүн хүлээдэг юм. Миний ялгуусан хайрт хөвгүүд Сионд үлдэж, тэдний юу олж авахыг бүх хүн харах бөгөөд энгүй их алдар суу та нарын өмнө гарч ирнэ. Энэ бол жаргалыг нь зүйрлэхүйеэ бэрх, үнэхээр агуу ерөөл билээ.

Долоон аянгын нүргээн гарах нь Намайг хайрладаг, Намайг үнэн зүрх сэтгэлээсээ хүсдэг хүмүүсийн аврал юм. Надад харьяалагддаг, Миний урьдаас тогтоосон болон сонгосон хүмүүс бүгд Миний нэрийн дор ирж чадна. Тэд Миний дуу хоолойг буюу Бурхан тэднийг дуудаж байгааг сонсож чадна. Би бол зөвт, Би бол итгэмжит, Би бол хайр, Би бол энэрэл, Би бол сүр жавхлан, Би бол дүрэлзэх гал, эцэст нь Би бол өршөөлгүй шүүлт гэдгийг газрын зах хязгаарынхан хараг.

Би бол жинхэнэ, бүрэн төгс Бурхан Өөрөө гэдгийг дэлхийд байгаа бүхэн хараг. Бүх хүн чин сэтгэлээсээ үнэмшиж, хэн ч Намайг дахин эсэргүүцэж, Намайг шүүж, Намайг гүтгэж зүрхлэхгүй. Тэгэх юм бол тэдэнд хараал тусаж, гамшиг тохиолдоно. Тэд өөрсдийнхөө сүйрлийг авчирч, мэгшин уйлж, шүдээ хавирч л чадна.

Төгс Хүчит Бурхан бол цор ганц жинхэнэ Бурхан гэдгийг бүх хүн мэдэг, орчлон даяар, газрын зах хязгаарт, айл бүрд, хүн бүхэнд мэдэгдүүл. Бүх хүн ар араасаа өвдөг сөгдөн Намайг шүтэн мөргөх ба дөнгөж хэлд орсон хүүхдүүд хүртэл “Төгс Хүчит Бурхан” хэмээн дуудах болно! Эрх мэдэл бүхий албан тушаалтнууд өмнө нь жинхэнэ Бурхан гарч ирэхийг нүдээрээ харах бөгөөд тэд ч мөн шүтэн мөргөж, түрүүлгээ харан унаад өршөөл, уучлал гуйх боловч үхэх цаг нь ирсэн учир хэтэрхий оройтсон байна. Тэдэнд ёроолгүй ангалд хаягдахаар яллагдаж, дуусах л үлдэх юм.

Би бүхэл бүтэн эрин үеийг төгсгөлд нь аваачиж, Өөрийн хаанчлалыг улам бэхжүүлнэ. Бүх улс үндэстэн, хүмүүс Надад мөнх захирагдана!

36-Р БҮЛЭГ

Төгс Хүчит жинхэнэ Бурхан, сэнтийд заларсан Хаан хамаг орчлонг захирч, бүх үндэстэн, бүх хүнтэй нүүр тулдаг бөгөөд тэнгэрийн доорх бүх зүйл Бурханы алдраар гэрэлтдэг. Орчлон ертөнц дээрх болон газар дэлхийн зах хязгаар хүртэлх бүх амьд зүйл харах болно. Уулс, гол, нуур, хуурай газар, далай тэнгис, бүх амьд зүйл жинхэнэ Бурханы нүүр царайн гэрэлд хөшгөө нээж, зүүднээс сэрэх мэт, үр нахиа хөрсийг нэвтлэн гарах мэт сэргэсэн байна!

Аяа! Цорын ганц жинхэнэ Бурхан дэлхий ертөнцийн өмнө гарч ирлээ. Түүнд хэн эсэргүүцлээр хандаж зүрхлэх вэ? Бүгд айн дагждаг. Бүгд бүрэн үнэмшиж, бүгд олонтоо уучлал гуйж, Түүний өмнө бүгд өвдөг сөхөрч, амтай бүхэн Түүнийг шүтэн мөргөдөг! Эх газар, далай, уулс, гол, бүх зүйл Түүнийг эцэс төгсгөлгүй магтдаг! Хавар цаг ирж, урьхан салхи үлээн, хаврын шиврээ бороог авчирна. Горхины урсгал хүн бүрийн адил уй гашуу, баяр хөөрөөр долгилж, өртэй байдлын, бас өөрийгөө зэмлэх сэтгэлийн нулимс унагана. Гол мөрөн, нуур, давлагаа, долгио бүгд дуулж, жинхэнэ Бурханы ариун нэрийг магтана! Магтаал нь үнэхээр тод цуурайтна! Нэгэн цагт Сатаны ялзруулсан хуучин зүйл бүгд нэг бүрчлэн шинэчлэгдэж, өөрчлөгдөж, цоо шинэ ертөнц рүү орно…

Энэ бол ариун бүрээний дуу, одоо сонсогдож эхэллээ! Чих тавигтун. Чихэнд чимэгтэй энэ дуу чимээ бол сэнтийн айлдвар бөгөөд үндэстэн, ард түмэн бүрд цаг ирснийг, эцсийн төгсгөл ирснийг тунхаглаж байна. Миний удирдлагын төлөвлөгөө дууссан. Миний хаанчлал газар дээр ил гарч ирсэн. Газрын хаанчлалууд Бурхан Миний хаанчлал боллоо. Миний долоон бүрээ сэнтийгээс дуугарч байна, үнэхээр гайхамшигт зүйлс тохиох болно! Газрын зах хязгаар бүрээс хүмүүс цасан нуранги мэт хүч түрж, аянга цахилгаан мэт эрчлэн зүг бүрээс хурдалцгаана. Зарим нь далайг гаталж, зарим нь онгоцоор нисэж, зарим нь бүхий л хэлбэр хэмжээтэй хөлөгт сууж, зарим нь морь унан ирж байна. Сайн хар даа. Анхааралтай сонс доо. Сэтгэл нь хөөрсөн, хүчирхэг, сүрдэм, зүс зүсний морьд унасан энэ морьтнууд тулааны талбараа эзэлж байгаа мэт үхлийг ч үл хайхарна. Жинхэнэ Бурханы төлөө хашхирах хүмүүсийн дуун, янцгаах морьдын төвөргөөн дунд үй олон эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд даруй гишгэчүүлэх болно. Зарим нь үхэж, зарим нь эцсийн амьсгалтайгаа үлдэж, зарим нь эрэмдэг зэрэмдэг болоод санаа тавих хүнгүй, бачимдан хашхирч, өвдсөндөө орь дуу тавина. Тэрслүү хөвгүүд! Та нарын эцсийн төгсгөл энэ биш гэж үү?

Миний дуу хоолойг сонсож, бүх үндэстэн, газар бүрээс цугласан Өөрийн ардыг хараад Би баярлана. Бүх хүн жинхэнэ Бурханы тухай байнга ярин, баярласандаа зогсолтгүй магтаж, дэвхэрнэ! Тэд дэлхий дээр гэрчлэл өргөдөг бөгөөд жинхэнэ

Бурханыг гэрчлэх тэдний дуу яг л их усны нүргэлэх чимээ адил билээ. Бүх хүн Миний хаанчлал руу шавна.

Миний долоон бүрээ дуугаран үүргэлж буй хүмүүсийг сэрээдэг! Хурдан бос, хэт оройтоогүй байна. Өөрийн амийг хар! Нүдээ нээгээд одоо ямар цаг болохыг хар. Эрж хайх юу байна? Бодох юм юу байна? Зуурах юм юу байна? Миний амийг олж авах болон өөрийн хайрладаг, зууралддаг юм бүхнээ олж авах хоёрын үнэ цэний ялгааг чи хэзээ ч бодож үзээгүй юм гэж үү? Дур зоргоороо байхаа боль, наадан тоглохоо ч боль. Энэ боломжийг бүү алд. Энэ цаг дахин ирэхгүй! Шууд босоод сүнсээ дасгалжуулж, Сатаны алив явуулга, арга залийг нэвт харж, саад хийхийн тулд янз бүрийн арга хэрэгсэл ашиглаж, Сатаныг ялан дийл, тэгснээр чиний амийн туршлага гүнзгийрч, Миний зан чанарыг амьдран харуулаад, амиа төлөвшүүлэн, хатуужуулж, Миний мөрийг үргэлж дагах болно. Бүү шантар, сул дорой бүү бай, замын шууд төгсгөл хүртэл алхам алхмаар, үргэлж урагшил!

Долоон бүрээ дахин дуугарах үед, энэ нь тэрслүү хөвгүүд, бүх үндэстэн болон ард түмнийг шүүлт рүү дуудсан дуудлага байх ба үндэстэн бүр Бурханы өмнө бууж өгнө. Бурхан алдар суут төрхөөрөө бүх үндэстэн, бүх ард түмний өмнө гарцаагүй гарч ирнэ. Хүн бүр бүрэн үнэмшиж, жинхэнэ Бурханыг тасралтгүй дуудан хашхирна. Төгс хүчит Бурхан илүү алдар суутай болж, Миний хөвгүүд Надтай хамт алдрыг хуваалцаж, хааны цол хэргэмийг хуваалцаж, бүх үндэстэн, бүх ард түмнийг шүүж, мууг шийтгэн, Надад харьяалагддаг хүмүүсийг аварч, өршөөн, хаанчлалыг бат бөх, тогтвортой болгоно. Долоон бүрээний дуугаар асар олон хүн аврагдан, өвдөг сөгдөж, Намайг тасралтгүй магтан шүтэн мөргөхөөр Миний өмнө буцан ирнэ!

Долоон бүрээ дахин нэгэнтээ дуугарах үед, энэ нь эрин үеийн төгсгөл хэсэг, диавол Сатаныг ялсан ялалтын бүрээн дуу, газар дээрх хаанчлалын ил тод амьдралыг эхлүүлэх ёслолын буудлага байх болно! Маш сүрлэг энэ дуу, сэнтийн эргэн тойронд цуурайтах энэ дуу, тэнгэр газрыг доргиох энэ бүрээн дуу бол Миний удирдлагын төлөвлөгөөний ялалтын тэмдэг буюу Сатаны шүүлт бөгөөд энэ дуу энэхүү хуучин ертөнцийг бүхэлд нь үхэл рүү, ёроолгүй нүх рүү ялладаг! Энэхүү бүрээн дуу нь нигүүлслийн хаалга хаагдаж, зөв, зүйтэй хаанчлалын амьдрал газар дээр эхлэхийг илтгэдэг юм. Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүсийг авардаг. Тэд Түүний хаанчлал руу буцмагц газар дээрх хүмүүст өлсгөлөн, тахал нүүрлэж, Бурханы долоон аяга буюу долоон гамшиг ар араасаа тохионо. Тэнгэр газар өнгөрөн одовч Миний үгс өнгөрөн одохгүй!

37-Р БҮЛЭГ

Миний байгаад итгэх итгэл та нарт үнэхээр дутагддаг бөгөөд үргэлж өөрсдөдөө найдаж үйлддэг. “Надгүйгээр та нар юу ч хийж чадахгүй!” Гэвч ялзарсан хүмүүс та нар Миний үгийг үргэлж нэг чихээрээ оруулаад нөгөө чихээрээ гаргачихдаг.

Өнөөгийн амьдрал бол үгийн амьдрал; үг үгүй бол амь үгүй, туршлага үгүй бөгөөд ямар ч итгэл байхгүй гэдгийг дурдахын ч хэрэггүй. Итгэл үгэн дотор байдаг; Бурханы үгэнд өөрсдийгөө илүү их зориулж байж л та нар бүх юмтай байж чадна. Өсөхгүй байх гэж бүү санаа зов: Амь өсдөг боловч хүмүүсийн санаа зовнилоос болж амь өсдөг юм биш.

Та нар үргэлж санаа зовомтгой байж, Миний зааврыг сонсдоггүй. Та нар үргэлж Надаас түрүүлж алхахыг хүсдэг. Энэ яг юу вэ? Энэ бол хүний хүсэл эрмэлзэл юм. Та нар Бурханаас ирж байгаа зүйл болон өөрсдөөсөө ирж байгаа зүйлийг тодорхой ялгах хэрэгтэй. Миний өмнө урам зоригийг хэзээ ч магтахгүй. Та нар Намайг нугаршгүй үнэнч сэтгэлээр эцсээ хүртэл дагаж чаддаг байгаасай гэж Би хүсдэг. Ингэж үйлдсэнээрээ Бурханд үнэнч байна гэж та нар итгэдэг. Сохор хүмүүсийг дээ! Та нар яагаад Миний өмнө илүү их ирж, эрж хайлгүй тэрүүхэндээ мунгинаж байдаг юм бэ? Та нар тодорхой харах ёстой! Эдүгээ ажиллаж байгаа нь гарцаагүй хүн биш, харин бүгдийн Захирагч, цор ганц жинхэнэ Бурхан—Төгс Хүчит билээ! Та нар үл ойшоох биш, харин ч өөрт байгаа бүхнээсээ байнга зуурах ёстой, учир нь Миний өдөр ойрхон байна. Тийм цаг үед та нар үнэхээр сэрэхгүй л байх гэж үү? Та нар тодорхой хараагүй л байна уу? Та нар дэлхий ертөнцтэй ханьссаар байгаа; үүнээс ангижирч чадахгүй. Яагаад? Та нар үнэхээр Намайг хайрладаг уу? Зүрх сэтгэлээ ил болгож Надад харуулж чадах уу? Бүх оршихуйгаа Надад өргөн барьж чадах уу?

Миний үгийн талаар илүү их бодож, үргэлж тодорхой ойлголттой бай. Будилж төөрөлдөн, хайнга хандаж болохгүй. Миний өмнө илүү их цаг өнгөрөөж, Миний цэвэр үгийг илүү их хүлээн авч, Миний санаа зорилгыг буруугаар бүү ойлго. Та нар Надаар өөр юу хэлүүлмээр байна? Хүмүүс хатуу сэтгэлтэй; үзэлдээ дэндүү их дарагдсан байдаг. Тэд арай ядан аргацааж байхад л хангалттай гэж үргэлж бодож, амиараа үргэлж тоглож байдаг. Мунхаг хүүхдүүд! Цаг оройтсон байна, одоо зугаа цэнгэл хөөж байх цаг биш. Нүдээ нээгээд ямар цаг ирснийг харах хэрэгтэй. Нар мандаж, газар дэлхийг гийгүүлэх гэж байна. Нүдээ нээгээд, сайтар хар; хайхрамжгүй бүү бай.

Энэ бол том асуудал, гэтэл та нар үүнийг ийнхүү тоглоом болгож, ингэж хандаж байдаг! Миний сэтгэл түгшиж байна, гэвч Миний зүрх сэтгэлд санаа тавьж, Миний сайн захиасыг сонсож, Миний зөвлөгөөг чагнаж чаддаг цөөн хүн байна! Үүрэг даалгавар хүнд боловч Миний төлөө ачаа хуваалцаж чадах хүмүүс та нарын дунд цөөхөн байна. Та нарт ийм хандлага байсаар байна. Өнгөрсөнтэй харьцуулахад та нар бага зэрэг ахиц гаргасан ч, үргэлж энэ үе шатандаа байгаад байж болохгүй! Би урагшаа маш хурдан алхаж байгаа ч та нарын хурд хэвээрээ л байна. Та нар өнөөдрийн гэрэл болон Миний алхаатай яаж хөл нийлүүлж чадах юм бэ? Цаашид бүү тээнэгэлз. Би та нарт ахин дахин онцолж хэлсэн: Миний өдөр цаашид хойшлогдохгүй!

Өнөөдрийн гэрэл өнөөдөртөө л хамаарах учир өчигдрийн гэрэлтэй харьцуулж, мөн маргаашийн гэрэлтэй ч харьцуулж болохгүй. Өдөр хоног өнгөрөх тусам шинэ

илчлэл, шинэ гэрэл улам хурц, улам тод болдог. Гайхширахаа боль, мунхаглахаа боль, хуучирсан арга барилтай зууралдахаа боль, Миний цагийг хойшлуулж, дэмий үрэхээ боль.

Сэрэмжтэй бай! Сэрэмжтэй бай! Надад улам их залбир, Миний өмнө илүү их цагийг өнгөрөө, тэгээд та нар гарцаагүй бүхнийг олж авна! Ингэвэл гарцаагүй бүхнийг олж авна гэдэгт итгэ!

38-Р БҮЛЭГ

Итгэл чинь сайн, цэвэр байгаа юм биш, харин Миний ажил гайхалтай байгаа хэрэг! Бүгд Миний өршөөлийн ач! Хувиа хичээсэн, биеэ тоосон ялзарсан зан чанар чамд өчүүхэн төдий ч байж болохгүй, эс бөгөөс Би чам дээр ажиллахгүй. Хүмүүсийн унах, бат зогсох эсэх нь тэднээс өөрсдөөс нь биш, харин Надаас болдог гэдгийг чи тодорхой ойлгох ёстой. Өнөөдөр чи энэ үе шатыг тодорхой ойлгодоггүй бол хаанчлалд орж чадахгүй нь лавтай! Өнөөдөр хийгдэж байгаа зүйл бол Бурханы гайхалтай ажил гэдгийг ойлгох ёстой; хүнтэй энэ ямар ч хамаагүй. Хүний үйлдэл ямар хэрэгтэй юм бэ? Нэг бол тэд аминч, биеэ тоосон, ихэрхүү байдаг, эсвэл Бурханы удирдлагад саад болж, төлөвлөгөөг нь сүйтгэж байдаг. Ай, ялзарсан хүмүүсийг дээ! Өнөөдөр та нар Надад найдаж эхлэх ёстой; тэгэхгүй бол чи юунд ч хүрэхгүй гэдгийг Би өнөөдөр чамд хэлье! Бүгд хий дэмий болж, ажил хэрэг чинь ямар ч хэрэггүй болно!

Цагийг дэмий бүү үр, бүү тээнэгэлз; Намайг хайрладаг хүн бүр дээр өнөөдөр Би гайхалтай ажлаа хэрэгжүүлнэ. Өөрсдийгөө даруу болгодоггүй хүмүүс Надад хэрэггүй, өнөөдөр Би зөвхөн бүрмөсөн даруу болсон хүмүүсийг л ашиглана. Намайг үнэн зүрхнээсээ хайрладаг, бусдад дорд үзэгддэг, өөрсдийгөө Надад бүрэн нээж чаддаг хүмүүст л Би өөрийгөө бүрэн нээнэ. Би чамд Өөрийн санаа зорилгыг ойлгуулна, мөн чи цаг үргэлж Миний өмнө байж, Миний ерөөлийг хүлээн авна. Өнөөдөр, Миний төлөө өөрсдийгөө зарлагаддаг, Миний төлөө өөрсдийгөө өргөдөг, Миний төлөө ачаа үүрдэг хүмүүст Би яасан ч шударга бус хандахгүй, ийнхүү Миний зөвт байдал илчлэгддэг. Миний талаар бүү гомдолло; Нигүүлсэл минь та нарт хангалттай. Чи зүгээр л хүрч ирээд үүнийг ав, тэгвэл чи юутай ч харьцуулшгүй сайхан амтыг мэдэрч болох юм. Энэ нь Намайг гэсэн хайрыг чиний дотор бий болгоод зогсохгүй тэрхүү хайрыг чинь бас гүнзгийрүүлнэ.

Миний ажил алхам алхмаар хэрэгждэг бөгөөд огтхон ч хайхрамжгүй юм уу замбараагүй биш. Намайг дагахын тулд та нар бас юмыг ингэж хийх ёстой. Миний зан байдлыг харж, Надаас суралц; ийм маягаар Миний мөрийг дагавал хаанчлалын илрэл рүү хүргэгдэнэ. Нэгэн дуугаар уухайл! Хөвгүүд минь! Бурханы ажил энэ бүлэг хүмүүс та нар дээр гүйцэлдэнэ. Та нар ерөөгдсөнөө мэдрэхгүй байна гэж үү?

Үүнийг ойлгоход үнэхээр хэцүү! Гайхалтай ажлыг минь хараасай гэсэндээ Би өнөөдөр та нарыг энд авчирсан!

39-Р БҮЛЭГ

Нүдээ нээгээд хар, Миний агуу хүч чадлыг чи хаа сайгүй харах болно! Чи хаана ч Надад итгэлтэй байж болно. Сансар огторгуй Миний агуу хүч чадлыг түгээж байна. Цаг агаарын дулаарал, цаг уурын өөрчлөлт, хүмүүсийн дундах гажуудал, нийгмийн хөдөлгөгч хүчний эмх замбараагүй байдал, хүмүүсийн зүрх сэтгэл дэх худал хуурмагт Миний хэлсэн үг биеллээ олчихсон. Нар цагаарч, сар улайна; энэ бүхэн тэнцвэрээ алдаж байна. Та нар эдгээрийг үнэхээр харахгүй л байна уу?

Бурханы агуу хүч чадал энд илчлэгддэг. Тэр бол хүмүүсийн олон жилийн турш эрэлхийлсэн—Төгс Хүчит—цорын ганц жинхэнэ Бурхан гэдэг нь эргэлзээгүй! Хэн үг айлдаад л аливааг бий болгож чаддаг вэ? Зөвхөн бидний Төгс Хүчит Бурхан. Түүнийг яримагц үнэн тэр даруй гарч ирдэг. Түүнийг жинхэнэ Бурхан гэж яаж хэлж болохгүй байх билээ?

Та нар бүгд Надтай хамтран ажиллахыг хүсэж байгааг Би сэтгэлийн гүндээ мэддэг бөгөөд Миний сонгосон хүмүүс, хайрт ах, эгч нар минь бүгд ийм хүсэл эрмэлзэлтэй ч орж эсвэл бодитоор хэрэгжүүлж чаддаггүй, бодит байдалтай нүүр тулаад биеэ барьж, тайван байж чаддаггүй. Та нар хэзээ ч Бурханы санаа зорилгыг анхаардаггүй, хувийн ашиг сонирхлоо түрүүнд тавьж, хүлээлгүйгээр өөрөө дур мэдэн үйлддэг. Ийм арга зам Миний санаа зорилгод хэзээ ч нийцэхгүй гэдгийг Би та нарт хэлчихье! Үр минь! Зүгээр л зүрх сэтгэлээ Надад бүрэн өгчих. Тодорхой бай! Би чиний мөнгийг ч, эд хөрөнгийг ч хүсдэггүй, мөн асар ихээр тэмүүлэн, хуурамч, ахархан бодолтойгоор Надад үйлчлэхээр Миний өмнө ирэхийг чинь ч хүсдэггүй. Асуудал гарах үед тайван, ариун зүрх сэтгэлтэй байж, хүлээж, эрж хай, Би чамд хариултыг нь өгөх болно. Бүү эргэлз! Яагаад Миний үгийг үнэн гэдэгт хэзээ ч итгэдэггүй юм бэ? Яагаад Миний үгэнд итгэж чаддаггүй юм бэ? Та нар бүр хэтэрхий зөрүүд, ийм цаг үед хүртэл хэвээрээ л байна; та нар хэтэрхий харанхуй бүдүүлэг, огтхон ч гэгээрээгүй! Та нар амин чухал үнэнээс хэр ихийг санаж байна вэ? Та нар үнэхээр үүнийг туулсан уу? Асуудалтай тулгарах үедээ та нар будилж, болгоомжгүй, яарч тэвдсэн үйлдэл хийдэг! Зүрх сэтгэлдээ асуудлыг үргэлж тунгаан боддогийн адил сүнсэнд орж, Надтай илүү их нөхөрлөх нь өнөөдөр гол зүйл юм. Ойлгож байна уу? Энэ бол гол нь! Оройтсон хэрэгжүүлэлт бол үнэндээ асуудал билээ. Хурдал, бүү алгуурла! Миний үгийг сонсдог, алгуурладаггүй, харин даруй хэрэгжүүлдэг хүмүүс асар ихээр ерөөгдөнө! Би та нарт хоёр дахин ихийг хайрлана! Санаа бүү зов! Секунд ч алгуурлалгүй Миний хэлснээр үйлд! Хүний үзэл чинь байнга ийм байдаг, та нар юмыг хойш тавьж, өнөөдөр хийх юмыг үргэлж маргааш болгож хойшлуулж байдаг. Ийм залхуу, ийм болхи. Үүнийг үгээр илэрхийлж чадахгүй нь! Би хэтрүүлээгүй—энэ бол бодит баримт. Хэрвээ чи үүнд итгэхгүй бол өөрийгөө анхааралтай ажиглаж, нөхцөл байдлаа шалга, үнэхээр тийм болохыг чи олж мэдэх болно!

40-Р БҮЛЭГ

Та нар яагаад ийм мулгуу юм бэ? Яагаад ийм хөшүүн юм бэ? Хэд хэдэн сануулга та нарыг сэрээсэнгүй; Намайг энэ бухимдуулж байна. Хөвгүүд минь ийм байхыг харах зүрх Надад үнэндээ алга. Зүрх сэтгэл минь яаж үүнийг тэвчиж чадах билээ? Ээ халаг! Би та нарыг Өөрийн гараар сургах хэрэгтэй болжээ. Миний алхаа хурдассаар байна. Хөвгүүд минь! Хурдан босоод Надтай хамтран ажилла. Хэн одоо Миний төлөө өөрийгөө чин сэтгэлээсээ зарлагадаж байна вэ? Хэн ганц ч үг гомдоллохгүйгээр өөрийгөө бүрэн зориулж чадаж байна вэ? Та нар үргэлж маш хөшүүн, мулгуу байдаг! Хэчнээн хүн Миний сэтгэлд санаа тавьж, хэн Миний үгийн Сүнсийг үнэхээр ухаарч чаддаг вэ? Би гагцхүү сэтгэл түгшин хүлээж, найдаж л чадна; та нарын хөдөлгөөн нэг бүр зүрх сэтгэлийг минь хангалуун болгож чадахгүй байгааг хараад Би юу хэлэх билээ? Хөвгүүд минь! Эцэгийн чинь өнөөдөр хийдэг бүхэн хөвгүүдийнхээ төлөө л байдаг. Миний хөвгүүд яагаад зүрх сэтгэлийг минь хэзээ ч ойлгож чаддаггүй юм бэ? Хөвгүүд минь яагаад Эцэг Миний санааг үргэлж зовоодог юм бэ? Хэзээ хөвгүүд минь өсөж том болж, Миний санааг зовоохоо больж, Намайг санаа амар байлгах вэ? Хэзээ Миний хөвгүүд бие даан амьдарч, өндийн босож, Эцэгийн мөрөн дээрх ачааг хөнгөлж чадах вэ? Би хөвгүүдийнхээ төлөө чимээгүйхэн нулимс л урсгаж, Бурханы удирдлагын төлөвлөгөөний биелэлтийн төлөө болон Өөрийн хайрт хөвгүүдээ аврах гэж хамгаа зориулдаг. Надад өөр сонголт үгүй.

Миний амлалтууд биелсэн, та нарын нүдний өмнө ил байна. Та нар яагаад Миний зүрх сэтгэлд санаа тавьж чаддаггүй юм бэ? Яагаад? Яагаад? Эдүгээг хүртэл чи тоолж үзсэн үү: Миний зүрх сэтгэлийг хангалуун болгож, чуулганыг тэтгэж тэжээсэн зүйл чи хэр ихийг хийсэн бэ? Үүнийг сайтар тунгаан бод, хайнга бүү бай. Ганц ч гэсэн үнэнийг бүү тавьж явуул. Зөвхөн гадаад үзэмжийг анхааралд мөн чанарыг орхигдуулж болохгүй. Үг, үйлдэл бүр, хөдөлгөөн нэг бүр чинь Христийн суудлын өмнөх шүүлтийг туулсан эсэх, мөн хуулбарлан дуурайж биш, харин амийн илэрхийллийг дотроосоо цацруулан шинэ хүний дүр төрхтэй болж өөрчлөгдсөн эсэхээ цаг үргэлж шинжилж байх ёстой. Хохирол амсахаас зайлсхийхийн тулд өөрийн амийг бүү саатуул. Хурдхан энэ нөхцөл байдлыг засаж, Миний зүрх сэтгэлийг хангалуун болго, мөн биеэ авч явах зарчмуудыг санаж яв: Аливаа зүйлийг зөвт байдалтайгаар, шулуун шударгаар үйлдэж, Миний зүрх сэтгэлийг хангалуун болго. Бодлогогүй бүү бай. Чи үүнийг санаж явж чадах уу?

41-Р БҮЛЭГ

Чуулган дотор үүсдэг асуудлуудын талаар тийм их болгоомжлол бүү тээ. Чуулганыг барих явцад алдаа байх нь зайлшгүй, харин асуудлуудтай нүүр тулах үедээ бүү сандарч тэвд; харин тайван байж, биеэ барь. Би та нарт аль хэдийн

хэлсэн бус уу? Миний өмнө байнга ирж, залбир, Би чамд Өөрийн санаа зорилгыг тодорхой харуулна. Чуулган бол Миний зүрх сэтгэл, мөн Миний эцсийн зорилго тул Би үүнийг хайрлахгүй байж яахан чадах билээ? Бүү ай—ийм зүйлс чуулган дотор тохиолдохдоо бүгд Миний зөвшөөрлөөр тохиолддог юм. Босоод Миний өмнөөс ярь. Бүх зүйл болон хэрэг явдлыг Миний сэнтий зөвшөөрсөн бөгөөд бүгд Миний санаа зорилгыг дотроо тээдэг гэдэгт итгэлтэй бай. Хэрвээ дур зоргоороо үргэлжлүүлэн нөхөрлөвөл асуудал үүснэ. Чи үр дагаварыг нь бодож үзсэн үү? Энэ бол Сатаны далимдуулан ашиглах зүйл юм. Миний өмнө байнга ир. Би ний нуугүй ярина: Хэрвээ чи Миний өмнө ирэлгүйгээр ямар нэгэн зүйлийг хийх гэж байгаа бол үүнийгээ гүйцэлдүүлж чадна гэж бүү төсөөл. Та нар л Намайг энэ байр сууринд албан хүчээр тавьсан.

Бүү урам хугар, бүү сул дорой бай, Би чиний хувьд аливааг тодорхой болгоно. Хаанчлалд хүрэх зам тийм ч дардан биш; юу ч тийм энгийн биш! Чи ерөөлүүдийг амархан авахыг хүсдэг, тийм биз дээ? Өнөөдөр хүн бүр гашуун шалгалттай нүүр тулна. Тийм шалгалтгүйгээр Намайг хайрлах зүрх сэтгэл чинь хүчтэй болохгүй бөгөөд Намайг гэх жинхэнэ хайргүй байх болно. Эдгээр шалгалт багахан орчин нөхцөл төдийхнөөс бүрддэг байсан ч гэсэн хүн бүр тэдгээрийг туулах ёстой; ердөө шалгалтын бэрхшээл нь нэгээс нөгөө хүнд ялгаатай байх болно. Шалгалтууд бол Надаас ирж буй ерөөл бөгөөд та нараас хэчнээн олон чинь үргэлж Миний өмнө ирж, Миний ерөөлийг гуйн өвдөг сөгддөг билээ? Тэнэг хүүхдүүд! Та нар үргэлж, сайныг бэлгэдсэн цөөн хэдэн үгийг л Миний ерөөл гэж тооцогдоно хэмээн боддог ч гашуун зовлон бол Миний ерөөлүүдийн нэг гэдгийг таньдаггүй. Миний гашуун зовлонг хуваалцдаг хүмүүс Миний жаргалыг гарцаагүй хуваалцана. Энэ бол та нарт өгөх Миний амлалт, Миний ерөөл юм. Миний үгийг идэж, ууж, эдлэхээс бүү цааргал. Харанхуй өнгөрөхөд гэрэлтэй болдог. Үүр цайхын өмнө хамгийн харанхуй байдаг; энэ цаг үеийн дараа тэнгэр бага багаар гэрэлтэж, дараа нь нар мандана. Бүү ай, бүү хулчий. Өнөөдөр Би хөвгүүдээ дэмжиж, тэдний төлөө эрх мэдэл эзэмшдэг.

Чуулганы ажил хэргийн тухайд гэвэл, хариуцлагаасаа үргэлж бүү зайлсхий. Хэрвээ чи хэрэг явдлыг Миний өмнө нухацтайгаар авчирвал замаа олох болно. Иймэрхүү ялихгүй асуудал тохиолдоход чи айж сандран, арга мухарддаг уу? “Надад үргэлж ойрт!” гэж Би маш олон удаа хэлсэн. Та нараас шаарддаг зүйлсийг минь та нар нухацтайгаар хэрэгжүүлсэн үү? Хэр олон удаа Миний үгийг тунгаан бодсон бэ? Хэрвээ бодоогүй бол та нарт ямар ч тодорхой мэдлэг ухаан алга. Энэ нь та нараас болсон бус уу? Та нар бусдыг буруутгадаг байж яагаад өөрсдийгөө үзэн яддаггүй юм бэ? Та нар аливааг баллаж түйвээгээд дараа нь хайнга, хааш яаш хэвээр үлддэг; та нар Миний үгэнд анхаарал хандуулах ёстой.

Дуулгавартай болон хүлцэнгүй хүмүүс агуу ерөөл хүртэнэ. Чуулганд Намайг гэрчлэхдээ бат зогсож, үнэнийг баримтал; зөв нь зөв, буруу нь буруу. Хар цагааныг бүү хольж хутга. Чи Сатантай дайтах бөгөөд дахин хэзээ ч босохгүй болтол нь үүнийг бүрэн ялах ёстой. Миний гэрчлэлийг хамгаалахын тулд чи бүхнээ өгөх

ёстой. Энэ нь үйлдлүүдийн чинь зорилго байх болно—үүнийг бүү март. Харин одоогоор та нарт итгэл болон аливааг ялган салгах чадвар дутаж, Миний үг болон Миний санаа зорилгыг ойлгож үргэлж чаддаггүй. Гэлээ ч гэсэн, сэтгэлээ бүү түгшээ; бүх зүйл Миний алхмын дагуу явагддаг ба сэтгэлийн түгшүүр гагцхүү төвөг учруулдаг. Миний өмнө илүү их цагийг өнгөрөөж, махан биед зориулсан хоол унд, хувцас хунарт ач холбогдол бүү өг. Миний санаа зорилгыг байнга эрж хай, тэдгээр нь юу болохыг Би чамд тодорхой харуулна. Аажмаар чи бүх зүйлээс Миний санаа зорилгыг олно, ингэснээр Би ямар ч саадгүйгээр хүн бүхэн дотор орох замтай болно. Энэ нь Миний зүрх сэтгэлийг хангалуун болгож, та нар Надтай хамт үүрдийн үүрд ерөөл хүртэнэ!

42-Р БҮЛЭГ

Төгс Хүчит Бурханы үйл хэрэг хэчнээн агуу юм бэ! Ямар гайхалтай юм бэ! Ямар гайхамшигтай юм бэ! Долоон бүрээ дуугарч, долоон аянга илгээгдэж, долоон аягатайг асгадаг—эдгээр нь тэр дороо ил тод үзэгдэх бөгөөд ямар ч эргэлзээ байхгүй. Бурханы хайр бидэн дээр өдөр бүр ирдэг. Зөвхөн Төгс Хүчит Бурхан биднийг аварч чадна; бид золгүй явдалтай учрах уу, эсвэл ерөөл хүртэх үү эсэх нь бүхэлдээ Түүнээс шалтгаалах ба хүмүүс бид үүнийг шийдэх ямар ч аргагүй. Өөрсдийгөө Бурханд бүхий л зүрх сэтгэлээсээ зориулдаг хүмүүс мэдээжийн хэрэг өгөөмөр ерөөл хүртдэг байхад өөрсдийн амийг хамгаалахаар хичээдэг хүмүүс амиа алдана; бүх зүйл болон бүх хэрэг Төгс Хүчит Бурханы гарт бий. Өөрийнхөө алхмыг ахин бүү зогсоо. Тэнгэр, газарт хүний нуугдах аргагүй асар их өөрчлөлт гарна. Гашуун зовлонд шаналан уйлахаас өөр сонголт түүнд үгүй. Ариун Сүнсний одоогийн ажлыг дага. Түүний ажлын хүрсэн алхмын талаар та нар дотроо бусдаар сануулалтгүйгээр тодорхой мэдэж байх хэрэгтэй. Одоо Төгс Хүчит Бурханы өмнө аль болох байн байн ирж, Түүнээс бүхнийг асуу. Тэр гарцаагүй дотроос чинь гэгээрүүлэх ба чухал цаг үеүдэд чамайг хамгаална. Бүү ай! Тэр хэдийн чиний бүхий л оршихуйг эзэмшдэг. Түүний хамгаалалт, халамж байхад чамд айх зүйл юу байна? Өнөөдөр Бурханы хүслийн биелэлт ойрхон байна, айсан хэн ч бай зөвхөн алдах болно. Миний чамд хэлж байгаа зүйл бол үнэн. Сүнслэг нүдээ нээ: Тэнгэр дорхноо өөрчлөгдөх болно, гэхдээ чамд айх зүйл юу байна? Түүний гарын ялимгүй хөдөлгөөнөөр тэнгэр, газар тэр дороо устах болно. Тиймээс хүн санаа зовоод юу хожих билээ? Бүх зүйл Бурханы гарт байдаггүй гэж үү? Хэрвээ Тэр, тэнгэр газарт өөрчлөгд гэж тушаавал тэд өөрчлөгдөнө. Хэрвээ Тэр биднийг бүрэн төгс болгуулна гэж хэлбэл бид бүрэн төгс болгуулна. Хүнд санаа зовох шаардлага байхгүй, гэхдээ тайвнаар урагшлах хэрэгтэй. Гэсэн хэдий ч хүн аль болох хянуур, сонор сэрэмжтэй байх ёстой. Тэнгэр агшин зуур өөрчлөгдөж болно! Хүн хэдий нүцгэн нүдээ бүлтийтэл нээгсэн ч нэг ихийг харах чадваргүй байдаг. Одоо анхааралтай бай.

Бурханы хүсэл гүйцэлдэж, Түүний ажил бүрэн төгс болж, Түүний төлөвлөгөө амжилт олж, Түүний хөвгүүд бүгд Түүний сэнтийн өмнө ирсэн. Тэд Төгс Хүчит Бурханы хамтаар суун бүх улс үндэстнийг болон ард түмнийг шүүхээр ирсэн. Чуулганыг хяхан хавчиж, Бурханы хөвгүүдийг зовоосон хүмүүс хатуу шийтгүүлэх нь мэдээж юм! Бурханд өөрсдийгөө чин сэтгэлээсээ өгч, бүхнийг баримталдаг хүмүүсийг Бурхан хэзээ ч өөрчлөгдөхгүйгээр үүрд мөнхөд хайрлах нь гарцаагүй!

43-Р БҮЛЭГ

Би та нарт сануулаагүй гэж үү? Битгий их санаа зов; та нар зүгээр л Намайг сонсдоггүй, үнэхээр бодлогогүй хүмүүс! Та нар Миний зүрх сэтгэлийг хэзээ ойлгож чаддаг болох вэ? Өдөр бүр шинэ гэгээрэл байдаг, өдөр бүр шинэ гэрэл байдаг. Үүнийг та нар өөрсдөө хэр олон удаа ухаарсан бэ? Би Өөрөө та нарт хэлсэн биш үү? Та нар, хатгасан үед л хөдлөх шавж мэт идэвхгүй байсаар байдаг ба Надтай хамтран ажиллаж, Миний ачаанд анхаарал хандуулахын тулд санаачилга гаргаж чаддаггүй. Би та нарын цовоо, сайхан инээмсэглэлийг харж, хөвгүүдийнхээ идэвхтэй, золбоотой байдлыг хармаар байгаа боловч чаддаггүй. Харин ч та нар ухаан муутай, тэнэг, мунхаг байна. Та нар эрж хайхын тулд санаачилга гаргах хэрэгтэй. Зоригтойгоор эрэлхийл! Зүгээр л зүрх сэтгэлээ нээж, Намайг дотроо амьдруул. Хянамгай бай, сонор сэрэмжтэй бай! Чуулган дахь зарим хүн хүмүүсийг мэхэлдэг бөгөөд аминд чинь нөлөөлж, хохирол учруулах вий гэсэндээ та нар энэ үгэнд үргэлж ихээхэн ач холбогдол өгч бай. Чи Миний төлөө өндийн босож, үг хэлэх зоригтой байх аваас Би энэ бүхний ачааг үүрч, чамд хүч өгнө гэдэгт бат итгэ! Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгаж байгаа цагт Би чамд Өөрийн инээмсэглэл, Өөрийн хүслийг үргэлж харуулна. Чи бат тууштай байж, хөвгүүний зан чанарыг амьдран харуулж байгаа цагт Би чамайг дэмжиж, чухал байр сууринд тавина. Миний өмнө ирэх үедээ зүгээр л Надад ойрт. Ярьж чадахгүй бол бүү ай. Чамд эрж хайсан зүрх сэтгэл байгаа цагт Би чамд үг өгнө. Надад сайхан сонсогддог үг хэрэггүй, зусардалт чинь ч хэрэггүй; Би ийм зүйлийг хамгийн их үзэн яддаг. Би ийм төрлийн хүнд хамгийн их дургүйцдэг. Тэд яг л Миний нүдэнд орсон хог, маханд зоогдсон өргөс мэт агаад тэднийг авч хаях хэрэгтэй. Эс бөгөөс Миний хөвгүүд Миний төлөө эрх мэдэл эзэмшиж чадахгүй бөгөөд дарангуй хяналтад өртөнө. Би яагаад ирсэн бэ? Өөрийн хөвгүүдийг дэмжиж, зоригжуулахын төлөө ирсэн, ингэснээр дарангуйлал, дээрэлхэлт, хүйтэн сэтгэл, хүчирхийллийг туулах тэдний өдрүүд үүрд үгүй болно!

Зоригтой бай. Би үргэлж чамтай хамт алхаж, чамтай хамт амьдарч, чамтай ярьж, чамтай хамт үйлдэнэ. Бүү ай. Ярихдаа бүү тээнэгэлз. Та нар дандаа л сэтгэл хөдөлсөн, айсан, хулчийсан байх юм. Чуулганы бүтээн байгуулалтад ашиггүй хүмүүсийг зайлуулах ёстой. Чуулган дахь, нөхцөл байдал нь сайнгүй, Миний үгийн

дагуу үйлдэж чаддаггүй хүмүүс үүнд багтдаг бөгөөд үл итгэгч эцэг эхийг чинь дурдахын ч хэрэггүй. Би тийм зүйлсийг хүсдэггүй. Тэднийг устгах ёстой ба нэг нь ч үлдэх ёсгүй. Зүгээр л гар хөлийнхөө хүлээсээс ангижир. Чи санаа зорилгоо нягталдаг, мөн санаа зорилго чинь ашиг, алдагдал, нэр төр, эд баялаг, хувийн харилцааны төлөө биш байгаа цагт Би чамайг дагалдаж, аливааг чамд зааж өгч, цаг үргэлж тодорхой удирдамж өгнө.

Ай, Хөвгүүд минь! Би юу хэлэх ёстой вэ? Хэдий Би энэ зүйлсийг хэлж байгаа ч та нар Миний зүрх сэтгэлийг хайхрахгүй, хулчийсан хэвээр л байна. Та нар юунаас айна вэ? Та нар яагаад хууль, дүрэмд хүлэгдсээр байна вэ? Би та нарыг чөлөөлсөн боловч та нарт одоо ч гэсэн эрх чөлөө алга. Яагаад энэ вэ? Надтай улам их ярилц, Би чамд хэлж өгнө. Намайг бүү турш. Би бол бодит. Надад худал хуурмаг үгүй; бүгд бодитой! Миний хэлдэг зүйл үнэн. Би хэзээ ч амласнаасаа буцдаггүй.

44-Р БҮЛЭГ

Би зөвт, Би итгэмжит, Би хүний далдын далд сэтгэлийг нягталдаг Бурхан! Хэн нь үнэн, хэн нь худлыг Би дор нь илчилнэ. Бүү түгш; бүх зүйл Миний цагаар ажилладаг. Хэн Намайг чин сэтгэлээс хүсдэг, хэн Намайг хүсдэггүйг Би та нарт нэг нэгээр нь хэлнэ. Зүгээр л сайн идэж, сайн ууж, Миний өмнө ирэхдээ Надад ойр дөхөхөө л бод, харин Би ажлаа Өөрөө хийнэ. Үр дүнг нь хурдан харах гэж хэт бүү бачимд, Миний ажил бол нэгмөсөн хийж болдог зүйл биш. Үүнд Миний алхам, Миний мэргэн ухаан оршдог учраас Миний мэргэн ухаан илчлэгдэж чаддаг юм. Өөрийн гараар юу хийдгээ, мууг шийтгэж, сайныг шагнадаг болохоо Би та нарт харуулна. Би лав хэнд ч давуу эрх олгодоггүй. Намайг чин үнэнээр хайрлагчийг Би чин үнэнээр хайрлах ба Намайг чин үнэнээр хайрладаггүй хүмүүстэй уур хилэн минь хэзээд хамт байна, ийнхүү тэд Намайг жинхэнэ Бурхан, хүний далдын далд сэтгэлийг нягталдаг Бурхан гэдгийг байнга санах болно. Бусдын нүүрэн дээр нэг янзаар, ар хударгаар нь өөр янзаар бүү авирла; Би хийдэг бүхнийг чинь тодорхой хардаг бөгөөд хэдий чи бусдыг хуурч болох ч Намайг хуурч чадахгүй. Би тов тодорхой хардаг. Аливааг нууж хаах боломж чамд үгүй; бүгд Миний гарт байна. Өчүүхэн тооцоолол чинь чамд ашигтайгаар эргэсний төлөө өөрийгөө маш ухаантай гэж бүү бод. Би чамд хэлье, хүн хэчнээн олон төлөвлөгөөг, мянга, түмээр нь гаргаж болох боловч эцэст нь тэд Миний гараас зугтаж чадахгүй. Миний гар ганц хүнийг байтугай бүх зүйл, бүх үйл явдлыг удирддаг! Надаас булталж, нуугдах гэж бүү оролд, аргалах юм уу, нуун далдлах гэж бүү оролд. Миний алдар суут төрх, Миний уур хилэн, Миний шүүлт нийтэд илчлэгдсэнийг чи хараагүй л байгаа юм биш биз дээ? Намайг чин сэтгэлээсээ хүсдэггүй хэнийг ч Би нэн даруй, ямар ч өршөөлгүй шүүх болно. Миний өрөвч сэтгэл дууссан; өөр үлдээгүй. Цаашид хоёр нүүртэй байхаа больж, цадиггүй, балмад явдлуудаа зогсоо.

Хүү минь, сэрэмжтэй бай; Миний өмнө илүү их цаг зарцуул, тэгвэл Би чамайг удирдах болно. Бүү ай, давхар ирт хурц илдийг минь гаргаж ирээд, Миний хүслийн дагуу Сатантай эцсээ хүртэл тулалд, Би чамайг хамгаална, бүү санаа зов. Нууцлагдсан бүх зүйл нээгдэж, илчлэгдэнэ. Би бол бүх харанхуйг энэрэлгүй гийгүүлэгч, гэрэл гаргагч Нар. Миний шүүлт бүрэн буусан; чуулган бол тулааны талбар. Та нар бүгдээрээ биеэ бэлдэж, чи бүхий л оршихуйгаа эцсийн шийдвэрлэх тулаанд зориулах хэрэгтэй; Би чамайг гарцаагүй хамгаална, тэгснээр чи Миний төлөө ялгууснаар, сайн тулалдах болно.

Болгоомжтой бай, өнөөгийн хүмүүсийн зүрх сэтгэл хуурамч, тааж мэдэшгүй бөгөөд тэдэнд итгэх аргагүй. Зөвхөн Би л та нарын төлөө бүхнээ зориулдаг. Миний дотор ямар ч заль мэх үгүй; зүгээр л Намайг түш! Миний хөвгүүд эцсийн шийдвэрлэх тулаанд гарцаагүй ялалт байгуулах бөгөөд Сатан үхэн хатан үзэлцэхээр гарч ирэх тун магадтай. Бүү ай! Би чиний хүч, Би чиний бүх зүйл. Аливааг байн байн бүү бод, тийм их бодолд дарагдаж болохгүй. Цаг дэндүү давчуу учир Би та нарыг замаар цаашид чирч явахгүй гэж өмнө нь хэлсэн. Та нарыг чихдэж аваад алхам тутамд сануулах цаг Надад өөр байхгүй—тэгэх боломжгүй! Та нар тулааны бэлтгэлээ л дуусга. Би чиний төлөө бүх хариуцлагыг үүрдэг; бүх зүйл Миний гарт. Энэ бол үхэх, сэхэхийн төлөөх тулаан бөгөөд аль нэг тал нь гарцаагүй сөнөнө. Гэхдээ Би бол үүрд ялгуусан бөгөөд дийлдэшгүй, харин Сатан гарцаагүй сүйрнэ гэдгийг чи мэдэх ёстой. Энэ бол Миний алхам, Миний ажил, Миний хүсэл, Миний төлөвлөгөө!

Дууссан! Бүгд дууссан! Бүү зүрх алд, бүү ай. Би чамтай, чи Надтай үүрдийн үүрд хаад байх болно! Би үг хэлсэн л бол үүрд хувирахгүй ба та нарт удахгүй үйл явдлууд тохиолдоно. Сонор бай! Та нар мөр бүрийг сайн тунгаах хэрэгтэй; Миний үгсийн талаар бүүр түүр төсөөлдөг байхаа боль. Тэдний талаар тодорхой мэдэж байх ёстой! Миний өмнө аль чадахаараа их цаг зарцуулна гэдгийг санаж явах ёстой!

45-Р БҮЛЭГ

Та нар олон нийтийн өмнө ах, эгч нарыгаа юу ч биш юм шиг шүүдэг. Та нар үнэхээр сайныг хорон муугаас ялгаж мэддэггүй; ичгүүрийг мэддэггүй! Энэ чинь асар увайгүй, зоргоороо ааш араншин биш гэж үү? Та нар бүгд будилж, уйтгар гунигт автдаг; чи маш их ачаа тээдэг ба Намайг гэх орон зай чиний дотор алга. Сохор хүмүүс! Хэрцгий авир чинь хэтэрчихжээ—энэ хэзээ дуусах юм бэ?

Би та нартай зүрх сэтгэлээсээ ахин дахин ярьж, Өөрт байгаа бүхнээ та нарт өгдөг боловч та нар маш харамч бөгөөд өчүүхэн төдий ч хүн чанаргүй; үүнийг ойлгоход үнэхээр хэцүү юм. Яагаад та нар өөрсдийн үзэлтэй зууралдана вэ? Намайг байлгах газар өөрийнхөө дотор гаргаад өгч яагаад чаддаггүй юм бэ? Би та нарт хор хөнөөл учруулж чадна гэж үү дээ? Чи цаашид ийм маягаар авирлах

ёсгүй—Миний өдөр үнэндээ холгүй байна. Битгий болгоомжгүй ярьж, ухаангүй авирла, эсвэл бүү тэмцэлд, төвөг бүү үүсгэ; энэ нь та нарын аминд ямар сайн зүйл авчирч чадах юм бэ? Би та нарт үнэнээсээ хэлж байна, Миний өдөр ирэхэд ганц ч хүн аврагдахгүй байсан ч гэсэн юмсыг Би мөн л Өөрийнхөө төлөвлөгөөний дагуу зохицуулна. Би бол төгс хүчит Бурхан гэдгийг чи мэдэх ёстой! Ямар ч юм, ямар ч хүн, ямар ч хэрэг Миний урагшлах алхамд саад болж зүрхлэхгүй. Өөрийнхөө хүслийг та наргүйгээр хэрэгжүүлэх арга Надад байдаггүй гэж та нар бодох хэрэггүй. Хэрвээ чи өөрийн амьтай ийм сөрөг байдлаар харьцвал чи зөвхөн өөрийнхөө амийг л сүйрүүлэх ба энэ нь Надад хамаагүй байх болно.

Ариун Сүнсний ажил тодорхой үе шат хүртэл ахисан ба гэрчлэл нь оргилд хүрсэн. Энэ бол илэрхий баримт. Хурдал, бүүдгэр нүдээ нээ, та нарт гаргасан Миний уйгагүй хүчин чармайлтыг бүү талаар болго, цаашид өөрсдийгөө бүү өөгшүүл. Та нар Миний өмнө сайн үйл хийх дуртай байдаг, гэвч Намайг байхгүйд та нарын үйлдэл болон ааш араншин Надад харагдахаар Миний өмнө байж чадах уу? Та нар сайныг муугаас ялгаж мэддэггүй! Та нар Намайг сонсдоггүй, Миний өмнө нэг зүйл, Миний ар хударгаар өөр нэгийг хийдэг. Би бол хүний зүрх сэтгэлийн гүнийг хардаг Бурхан гэдгийг та нар ухаараагүй л явна. Та нар дэндүү мунхаг юм!

Хожим та нар урагшлах замдаа арга заль зохиож, хууран мэхлж, шударга бус зан гаргах ёсгүй, эс бөгөөс үр дагавар нь төсөөлшгүй байх болно! Мэхлэлт болон шударга бус зан гэж юу болохыг та нар бүгдээрээ бас л ойлгохгүй байна. Надад харуулж болохгүй, олонд ил тод болгож болохгүй аливаа үйлдэл, ааш араншин бол мэхлэлт ба шударга бус зан юм. Одоо чи үүнийг ойлгох ёстой! Хэрвээ чи ирээдүйд залилан мэхлэх ба шударга бус зан гаргавал ойлгоогүй дүр бүү үзүүл—ийм юм хийвэл чи мэдсээр байж буруу юм хийж байгаа тул хоёр дахин их гэм буруутай юм. Энэ нь та нарыг зөвхөн галд шатаагдахад юм уу, тэрнээс ч дор, өөрсдийгөө сүйрүүлэхэд хүргэнэ. Та нар ойлгох ёстой! Өнөөдөр та нарт тулгарч байгаа зүйл бол хайрын цээрлүүлэлт; мэдээжийн хэрэг энэ нь цэвдэг шүүлт биш. Хэрэв чи үүнийг ойлгож чадахгүй бол үнэхээр өрөвдөлтэй бөгөөд зүгээр л ямар ч найдваргүй юм. Хэрвээ та нар хайрын цээрлүүлэлтийг хүлээж авахыг хүсэхгүй бол та нарт тохиолдох бүхэн нь цэвдэг шүүлт байна. Үүнийг тохиолдох үед Намайг сануулж хэлээгүй гэж бүү гомдоллоорой. Хариуцлагаасаа зайлсхийсэн нь Би биш, харин Миний үгийг сонсоогүй, Миний үгийг хэрэгжүүлээгүй та нар юм. Хожим хүмүүс Намайг буруутгаж болзошгүй тул Би үүнийг одоо хэлж байна.

46-Р БҮЛЭГ

Миний төлөө өөрийгөө чин сэтгэлээсээ зарлагадаж, өргөн барьдаг хэнийг ч бай Би гарцаагүй эцсийг нь хүртэл хамгаална; Миний гар чамайг бат атгана, ингэснээр чи үргэлж амар тайван, баяр хөөртэй байж, өдөр бүр Миний гэрэл болон илчлэлтэй

байна. Би чамд өгөх ерөөлөө гарцаагүй хоёр дахин ихэсгэнэ, ингэснээр чи Надад байгаа зүйлийг авч, Миний юу болохыг эзэмшдэг. Чамд өгдөг зүйл бол чиний амь бөгөөд хэн ч үүнийг чамаас авч чадахгүй. Өөртөө төвөг бүү уд, сэтгэл гутралд бүү ор; Миний дотор зөвхөн амар амгалан, баяр хөөр л бий. Намайг чин сэтгэлээсээ анхаарч, дуулгавартай байдаг хүүхэд чамайгаа Би чин сэтгэлээсээ хайрладаг. Миний хамгийн их үзэн яддаг хүмүүс бол хоёр нүүртнүүд; Би тэднийг гарцаагүй үгүй хийх болно. Би Өөрийн гэрээс дэлхийн үнэрийг, Өөрийн харж тэвчдэггүй тэр бүх зүйлийг таягдан хаяна.

Яг хэн Намайг чин сэтгэлээсээ хүсдэг, хэн хүсдэггүйг Би зүрх сэтгэлдээ мэддэг. Хэдийгээр тэд өөрсдийгөө сайтар өнгөлөн далдалж, дүр эсгэж, тэр ч бүү хэл тэднийг дэлхийн хамгийн сайн жүжигчид гэж хэлж болох боловч зүрх сэтгэлдээ агуулж буй бүхнийг нь Би тодорхой хардаг. Зүрх сэтгэлд чинь юу байгааг Намайг мэддэггүй гэж бүү бод; үнэн хэрэгтээ Надаас илүү тодорхой ойлгох хэн ч байхгүй. Чиний зүрх сэтгэлд юу байгааг Би мэднэ; чи өөрийгөө Бурханд өргөн барьж, Бурханы төлөө зарлагадахыг хүсдэг, зөвхөн чи л бусдыг баясгахын тулд бялдуучлахыг хүсдэггүй. Сайн хар! Өнөөдрийн хаанчлал хүний хүч тэнхээгээр бүтээгүй, харин Миний олон мэргэн ухаан, уйгагүй хичээл зүтгэлийг бүрэн ашиглаж амжилттай бүтээн байгуулна. Дотроо мэргэн ухаан хийгээд Би юу болохыг эзэмшдэг хэн боловч хаанчлалын бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулна. Дахин бүү санаа зов; дотор чинь байгаа Миний хүслийн илчлэл, гэрэлтүүлэлтийг үл хайхран чи үргэлж маш их санаа зовж байна. Цаашид бүү ингэ. Чи өөрийнхөө үйлдлээс болж зовохоос зайлсхийхийн тулд аливаа зүйлийн талаар Надтай илүү их нөхөрлө.

Магадгүй гаднаа Би хүн болгонд хайхрамжгүй байгаа мэт харагддаг боловч дотроо юу боддогийг минь чи мэдэх үү? Би даруу нэгнийг үргэлж өндөрт өргөж, биеэ тоон, өөрийгөө чухалчилдаг хүмүүсийг үргэлж доош нь буулгадаг. Миний хүслийг ойлгодоггүй хүмүүс асар их хохирол амсана. Энэ бол Би юу болох, энэ бол Миний зан чанар гэдгийг чи мэдэх ёстой—хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, хэн ч үүнийг бүрэн ойлгож чадахгүй. Миний илчлэлээр л дамжуулан чи ойлгож чадна, эс бөгөөс чи ч бас үүнийг бүрэн дүүрэн ойлгохгүй; биеэ бүү тоо. Зарим хүн сайн ярьж магадгүй ч зүрх сэтгэл нь хэзээ ч Надад үнэнч байдаггүй, үргэлж нууцаар Надтай сөргөлдөж байдаг; Би иймэрхүү хүнийг шүүх болно.

Зүгээр л бусдаас сэжүүр хайхад бүү анхаар, чи Миний зан төрх, хэв маягт анхаарлаа хандуулах ёстой. Ийм маягаар л чи Миний хүслийг аажмаар ухаарч эхэлнэ; тэр үед чиний үйлдэл Миний хүсэлтэй нийцэж, чи ямар ч алдаа гаргахгүй. Бүү уйл, бүү гашууд; Би чиний хийдэг бүхнийг, бүх зан авирыг чинь, боддог бүхнийг чинь тодорхой хардаг бөгөөд чин сэтгэлийн хүсэл эрмэлзлийг чинь мэднэ; Би чамайг ашиглах болно. Одоо маш чухал үе; чамайг турших цаг ирлээ. Чи одоо болтол хараагүй гэж үү? Чи хараахан ухамсарлаагүй л байна уу? Би чамд яагаад ийм хандлага гаргадаг вэ? Чи мэдэх үү? Би чамд эдгээр зүйлийг илчилсэн ба чамд бага зэрэг ойлголт бий. Гэвч бүү зогс—оролтоо шамдан үргэлжлүүл, тэгвэл Би

чамайг үргэлжлүүлэн гэгээрүүлнэ. Надад дуулгавартай байж, Намайг анхаарах тусам, дотор чинь улам гэрэлтэж, дотроо улам их илчлэлтэй болж байгаагаа чи ухаарсан уу? Надад дуулгавартай байж, Намайг анхаарах тусам, Миний талаар илүү их мэдлэгтэй болж, улам их туршлагатай болж байгаагаа чи мэддэг үү? Өөрийн үзэлтэй үргэлж бүү зууралд; ингэх нь Миний амьд усны урсгалыг хааж, Миний хүслийг хэрэгжүүлэхэд саад болно. Нэг хүнийг бүрэн олж авах нь амар зүйл биш гэдгийг чи мэдэх ёстой. Төвөгтэй байдлаар бүү бод. Зүгээр л дага, бүү эргэцүүлэн бод!

47-Р БҮЛЭГ

Зөвт байдлын Төгс Хүчит Бурхан—Төгс Хүчит! Танд ерөөс юу ч нуугдмал биш. Хүмүүсийн хэзээ ч олж нээгээгүй, балар эртний үеэс өнө мөнхөд хүртэлх нууц нэг бүр Таны дотор илэрхий, тов тодорхой байдаг. Бид цаашид эрж хайж, тэмтчих шаардлагагүй, учир нь өнөөдөр Таны үнэн бие бидэнд ил тод харагддаг, Та бол илчлэгдсэн нууц, Та бол бодитой Бурхан Өөрөө; өнөөдөр Та бидэнтэй нүүр тулан уулзсан бөгөөд Таны үнэн биеийг харахдаа бид сүнсний ертөнцийн бүх нууцыг хардаг. Энэ бол үнэхээр хэн нэгний төсөөлж чадах зүйл биш! Та өнөөдөр бидний дунд, бүр бидний дотор байж, бидэнд маш их ойрхон байгаа; үүнийг дүрсэлж хэлэхийн аргагүй! Доторх нууц нь зүйрлэшгүй!

Төгс Хүчит Бурхан Өөрийн удирдлагын төлөвлөгөөг гүйцэлдүүлсэн. Тэр бол орчлон ертөнцийн ялгуусан Хаан. Бүх зүйл, бүх юмыг Түүний гар хянадаг. Бүх хүн өвдөг сөгдөн шүтэн мөргөж, жинхэнэ Бурханы нэрийг—Төгс Хүчитийг дуудаж байна. Түүний амнаас гарсан үгээр бүх зүйл хийгддэг. Яагаад та нар маш их залхууран, Бурхантай хамт ажиллаж, Түүнтэй ойр нэгдэж, алдар суу руу Түүнтэй хамт явж чаддаггүй юм бэ? Та нар зовохыг хүсдэг юм гэж үү? Хаягдахыг хүсдэг юм гэж үү? Хэн Надад чин сэтгэлээсээ өөрийгөө зориулдгийг, хэн Миний төлөө чин сэтгэлээсээ өөрийгөө зарлагаддагийг Намайг мэдэхгүй гэж та нар бодож байна уу? Мунхаглал! Тэнэгүүд! Та нар Миний санаа зорилгыг танин мэдэж чадахгүй, Миний ачаанд хайхрамжтай байх нь бүү хэл, үргэлж өөрсдийнхөө төлөө Миний санааг зовоож, Намайг уйгагүй ажиллуулдаг. Хэзээ энэ дуусах юм бэ?

Бүх зүйл дээр Намайг амьдран харуулж, бүх зүйл дээр Намайг гэрчлэх—ингэх нь зүгээр л амаа нээж, хэдхэн үг холбох явдал уу? Та нар сайн муугийн ялгааг мэддэггүй! Өөрсдийнхөө хийдэг зүйлийг та нар Надгүйгээр хийдэг, өдөр тутмын амьдралд чинь Би бүр ч байдаггүй. Та нар Бурханд итгэх нь ноцтой зүйл гэж үздэггүйг Би мэднэ, иймд эдгээр нь та нарын үүрэх үр дүн! Та нар сэрээгүй хэвээр байгаа бөгөөд ийм маягаар үргэлжлүүлэх юм бол Миний нэрийг шившиглэх болно.

Өөрөөсөө асуу, чамайг ярихад Би хамт байдаг уу? Идэх юм уу хувцсаа өмсөхөд чинь Миний амлалт тэнд байдаг уу? Та нар үнэхээр бодлогогүй! Асуудлыг чинь

шууд хэлэхгүй байх болгонд үнэн төрхөө харуулдаг ба та нарын хэн нь ч үгэнд оромтгой биш. Хэрвээ ийм байгаагүй бол та нар өөрсдийгөө агуу гэж бодох байсан, дотроо олон зүйл эзэмшдэг гэж бодох байсан. Та нар дотроо Сатаны бузар муухай төрхөөр дүүрэн гэдгээ мэддэггүй гэж үү? Энэ бүх зүйлийг шавхан гаргахын тулд Надтай цуг ажилла. Миний юу болох болон Надад байгаа зүйлээр доторхоо бүрэн дүүргэ; тэгж байж л Намайг амьдран харуулж, илүү бодитоор Намайг гэрчилж, илүү олон хүн Миний сэнтийн өмнө захирагдах учир шалтгаан болж чадна. Мөрөн дээрх ачаа чинь ямар хүнд болохыг та нар мэдэх ёстой: Христийг өргөмжилж, Христийг харуулж, Христийг гэрчил, тэгснээр үй олон хүн аврал хүртэж, Миний хаанчлал бат бөх, ганхашгүй хэвээр үлдэнэ. Та нарыг өнөөдрийн ажлын ач холбогдлыг ойлголгүй, зүгээр л аргацаах вий гэсэндээ Би энэ бүгдийг онцолдог.

Асуудалтай нүүр тулахаараа арга мөхөстөж, халуун хайруулын тавган дээрх шоргоолж шиг тойрон гүйдэг: энэ бол та нарын зан чанар. Гаднаа та нар насанд хүрэгчид шиг харагддаг ч дотоод амь чинь хүүхдийнх шиг; Надад төвөг удаж, Миний ачааг л нэмэгдүүлдэг. Хэрвээ Надад Өөрийнхөө санааг өчүүхэн ч чилээдэггүй зүйл гэж байдаг бол тэр нь та нарын төвөг уддаг байдал. Тийм биш гэж үү? Өөрийгөө бүү зөвтгө. Миний хэлдэг зүйл бол үнэн. Намайг зүгээр л сүрлэг үг хэрэглэж, та нарт байнга сургамжилж байна гэж үргэлж бүү бод; энэ бол та нарын бодит нөхцөл байдал.

48-Р БҮЛЭГ

Би түгшиж байна, гэвч та нарын дундаас хэчнээн нь Надтай ижил оюун санаа, бодолтой байх чадвартай вэ? Чи Миний үгийг огт анхааралгүй, бүрэн үл тоомсорлодог бөгөөд тэдгээрт анхаарлаа төвлөрүүлж чаддаггүй, харин ч өөрийнхөө өнгөц зүйлд л төвлөрдөг. Та нар Миний уйгагүй тусламж, хүчин зүтгэлийг хог мэт үздэг; мөс чанар чинь яллагддаггүй гэж үү? Та нар мэдлэггүй, эрүүл ухаанаар дутмаг; та нар бүгд тэнэг бөгөөд Намайг сэтгэл хангалуун байлгаж огт чаддаггүй. Би бүхэлдээ та нарын төлөө байхад та нар хэр их Миний төлөө байж чадах вэ? Та нар Миний санаа зорилгыг буруу ойлгосон, энэ нь үнэхээр та нарын харалган байдал, аливааг нэвт харах чадваргүй байдал бөгөөд үргэлж та нарын төлөө санаа зовж, та нарт цаг зарцуулахад Намайг хүргэдэг. Тэгвэл та нар хэр их цагийг Миний төлөө зарцуулж, зориулж чадах вэ? Та нар эдгээр асуултыг өөрсдөөсөө илүү их асуух хэрэгтэй.

Миний санаа зорилго бүхэлдээ та нарын төлөө л байдаг—та нар үүнийг үнэхээр ойлгож байна уу? Та нар үүнийг үнэхээр ойлгосон бол аль эрт Миний санаа зорилгыг ойлгож, Миний ачаанд санаа тавьдаг болох байсан юм. Дахин хайхрамжгүй бүү бай, эс тэгвээс Ариун Сүнс та нарын дотор ажиллахгүй, энэ нь сүнсийг чинь үхүүлж, Үхэгсдийн орон руу унагаана. Энэ чамд дэндүү аймшигтай биш гэж үү? Би та нарт дахин сануулах шаардлагагүй. Та нар мөс чанараа хайж,

өөрсдөөсөө ингэж асуух ёстой: Би та нарыг хэтэрхий их өрөвддөг үү, эсвэл та нар Надад дэндүү их өртэй юу? Зөв бурууг бүү эндүүр; эрүүл ухаангүй бүү бай! Одоо бол эрх мэдэл, ашиг хонжооны төлөө тэмцэх юм уу хуйвалдаанд оролцох цаг биш. Харин ч аминд маш хор хөнөөлтэй эдгээр зүйлийг хурдхан хойш тавьж, бодит байдал руу орохоор эрж хайх ёстой. Та нар маш хайхрамжгүй! Та нар Миний зүрх сэтгэлийг ойлгож, Миний санаа зорилгыг ухаарч чаддаггүй. Миний хэлэх ёсгүй байсан олон зүйл байгаа, гэвч та нар ойлгодоггүй, үнэхээр будилсан хүмүүс учраас Би тэдгээрийг ахин дахин хэлэх ёстой болсон, тэгсэн ч гэсэн та нар Миний зүрх сэтгэлийг одоо хүртэл хангалуун болгож чадсангүй.

Та нарыг хуруу даран тоолбол хэчнээн нь Миний зүрх сэтгэлд чин сэтгэлээсээ санаа тавьж чадах вэ?

49-Р БҮЛЭГ

Харилцан уялдаж үйлчлэхдээ хүн зөв, эрч хүчтэй, золбоотой зохицуулах ёстой. Түүнчлэн, хүн тамир тэнхээтэй, эрч хүчтэй, итгэл дүүрэн байх ёстой, тэгж байж түүнийг харахад бусад хүн хангагдаж, дүүрэн болно. Надад үйлчлэхдээ та нар Миний зорьсноор үйлчилж, Миний зүрх сэтгэлд нийцээд зогсохгүй, санаа зорилгыг минь хангах ёстой, тэгснээр чамд гүйцэтгэдэг зүйлдээ Би сэтгэл хангалуун байна. Амьдралаа Миний үгээр дүүргэж, үг яриагаа Миний хүч чадлаар дүүргэ, энэ бол Миний чамаас хүсэх зүйл. Хүслээ дагаад чи Миний төрхийг илчилдэг үү? Тэглээ гээд Миний зүрх сэтгэлийг хангалуун болгох уу? Чи Миний санаа зорилгыг чин сэтгэлээсээ ажигласан хүн мөн үү? Зүрх сэтгэлийг минь ойлгохоор үнэхээр хичээсэн хүн чи мөн үү? Чи өөрийгөө үнэхээр Надад өргөн барьсан уу? Өөрийгөө үнэхээр Миний төлөө зарлагадсан уу? Чи Миний үгийг тунгаан бодсон уу?

Хүн бүх талаар мэргэн ухаан ашиглах ёстой, Миний төгс замаар алхахын тулд мэргэн ухаан ашиглах ёстой. Миний үгийн хүрээнд үйлддэг хүмүүс бол хамгийн ухаантай нь, Миний үгийн дагуу үйлддэг хүмүүс хамгийн дуулгавартай нь билээ. Миний хэлсэн зүйл хэрэгждэг, чи Надтай мэтгэлцэж, Надад учирлах гэж оролдох хэрэггүй. Би чамайг оюун санаандаа бодон хэлдэг бүхнээ хэлдэг (Би хатуу байна уу, зөөлөн байна уу хамаагүй). Чи дуулгавартай байхад анхаарвал зүгээр байх болно, энэ нь жинхэнэ мэргэн ухааны зам (бас Бурханы шүүлт чам дээр буухаас сэргийлэх зам) юм. Өнөөдөр, Миний гэрт Миний нүүрэн дээр эелдэг мөртөө Миний ардуур өөр зүйл бүү ярь. Би та нараас бодитой байхыг хүсдэг; та нар уран гоё үг хэрэглэх хэрэггүй. Бодитой хүмүүсийн хувьд бүх зүйл байдаг. Бодитой бус хүмүүсийн хувьд юу ч байхгүй. Тэдний бие хүртэл оршин байхаа болино, учир нь бодит байдалгүйгээр хоосон чанар л үлддэг; өөр тайлбар байхгүй.

Би та нарыг Бурханд итгэхдээ чин сэтгэлээсээ хандаж, юу олж авч, алдаж болох талаар ч, өөртөө байгаа бүхнийг ч бодохгүй байгаасай гэж хүсдэг; чи зөвхөн үнэн

зам дээр хөл тавихаар эрж хайх хэрэгтэй, хэн нэгний нөлөөнд автах юм уу хяналтад орох ёсгүй. Үүнийг чуулганы багана, хаанчлалын ялагч байх гэдэг; эсрэгээр нь хийх нь чи Миний өмнө амьдрахад зохисгүй гэсэн үг юм.

Өөр өөр нөхцөл байдалд Надтай ойр байх арга зам мөн адил өөр өөр байдаг. Зарим хүн Миний өмнө гоё үг хэлж, сүсэгтэй аашлах дуртай. Харин нүднээс далдуур тэд бүхэлдээ эмх замбараагүй байдаг бөгөөд тэдэнд Миний үг огт байдаггүй. Тэд ой гутмаар бөгөөд ядаргаатай; тэд хэн нэгнийг сургамжилж, хангаж огт чадахгүй. Та нар Надтай илүү ойр байж, нөхөрлөж чаддаггүйгээсээ болоод Миний зүрх сэтгэлийг анхаарч чаддаггүй; тэгээд та нарын төлөө байнга санаа зовж, шаргуу ажиллахад Намайг хүргэдэг.

50-Р БҮЛЭГ

Бүх чуулган, бүх ариун хүн өнгөрснөө бодож, ирээдүйгээ харах хэрэгтэй: Өнгөрсөн дэх хэр олон үйлдэл чинь хүлээн зөвшөөрөгдөж, хэд нь хаанчлалыг бүтээн байгуулахад хувь нэмэр болсон бэ? Өөрийгөө ухаантай гэж бүү бод! Өөрийнхөө дутагдлыг тодорхой харж, нөхцөл байдлаа ойлгох хэрэгтэй. Энэ тухайд зүтгэл гаргах юм уу цаг зарцуулахыг та нарын хэн нь ч хүсдэггүй учраас ямар ч ололт гаргаж чадахгүй байгааг Би мэднэ. Та нар бүх цаг заваа идэж, ууж, зугаацан, дэмий үрдэг. Та хэд цуглахдаа нэгнээ амиар хангах, амийн сүнслэг хэрэг явдлын талаар нөхөрлөхөд анхаарал тавилгүй, тоглож нааддаг. Тэнэг мөртөө инээж хөхрөн ярьж байгааг чинь Би харж тэвчдэггүй. Би олон удаа хэлсэн боловч та нар Миний хэлдэг зүйлийн утгыг мэддэггүй—энэ нь хамрын чинь үзүүр дээр байгаа мэт ойлгомжтой биш байна гэж үү? Би өмнө нь энэ мэт зүйл хэлж байсан ч та нар мөн л үнэмшдэггүй, хэлснийг минь хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд Би та нарыг буруугаар ойлгодог, бас Миний хэлж байгаа зүйл бодит биш гэж боддог. Аль эсвэл тийм биш юм уу?

Хэрвээ чи Надад хааш яаш хандвал Би чамайг хойш тавина. Дахиад хааш яаш байх гээд үзээрэй! Бодлогогүй, хайнга байх гээд үзээрэй! Миний үг бол сийлбэрийн хутга; хүсэлтэй минь нийцээгүй юуг ч энэ хутгаар тасална, чи өөрийгөө хүндэтгэхэд хэт их ач холбогдол өгөх хэрэггүй. Би чамайг хэлбэрт оруулж, Өөрийн хүсэлд нийцүүлэн сийлнэ. Миний зүрх сэтгэлийг буруугаар бүү ойлго; зүрх сэтгэлийг минь аль болох анхаарч байвал энэ нь хүлээн зөвшөөрөгдөх болно. Хэрвээ чи өчүүхэн ч болов анхаарал хандуулбал Би чамд дургүйцэхгүй! Санаа зовох юмгүйгээр үргэлж бүү үл тоо; Миний хүсэл чам дээр байнга гүйцэлдэхийг зөвшөөр.

Үй түмэн ариун хүмүүс бүгд өөр өөр байр суурьтай тул та нар бүгд мэдээж өөр өөр үүрэгтэй. Гэвч та нар Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагадахын тулд чадах бүхнээ хийх ёстой; чадах бүхнээ хийх нь та нарын үүрэг юм. Үүнд үнэнч байж, уриалгахнаар бэлэн байх хэрэгтэй. Хайнга байж үнэхээр болохгүй! Эс тэгвээс,

Миний шүүлт та нар дээр байнга бууна; бие махбод, сүнс, сэтгэл чинь үүнийг тэсэж чадахгүй бөгөөд чи уйлж, шүдээ хавирах болно.

51-Р БҮЛЭГ

Өө! Төгс Хүчит Бурхан! Амен! Таны дотор бүгд чөлөөлөгдсөн, бүгд чөлөөтэй, бүгд нээлттэй, бүгд илчлэгдсэн, бүгд гэрэл гэгээтэй, өчүүхэн төдий ч нуугдаж, далдлагдаагүй байдаг. Та бол бие махбодтой болсон Төгс Хүчит Бурхан. Та Хаан болон хаанчилсан. Та илэн далангүй илчлэгдсэн—цаашид нууц байхаа больсон, харин Та үүрдийн үүрд бүрэн илчлэгдсэн! Би үнэхээр бүхэлдээ илчлэгдэж, ил тод ирсэн бөгөөд Би зөвт байдлын Нар болж гарч ирсэн, учир өнөө үе цаашид үүрийн цолмон харагддаг эрин байхаа больсон, далд нууцлаг үе шат байхаа ч больсон. Миний ажил цахилах аянга мэт байдаг; гэнэтийн аянгын нижигнээн шиг хурдан гүйцэлддэг. Миний ажил одоогийн энэ үе шат хүртэл ахисан ба дэмий сэлгүүцэж, эсвэл цагаа дэмий үрдэг хэн ч бай гагцхүү өршөөлгүй шүүлттэй тулгарна. Ялангуяа, Би бол сүр жавхлан болон шүүлт гэдгийг, мөн Би та нарын төсөөлдөг шиг энэрэл, хайр байхаа больсон гэдгийг чи тодорхой ойлгох ёстой. Хэрвээ энэ зүйлийг тодорхой ойлгохгүй байсаар байвал чи гагцхүү шүүлтийг л хүлээн авна, учир нь танин мэдэж чадаагүй зүйлээ чи өөрөө амтална; эс тэгвээс чамд эргэлзсэн хэвээр байх бөгөөд итгэлдээ бат зогсож зүрхлэхгүй.

Миний даалгасан зүйлийг та нар сүсэг бишрэлтэйгээр гүйцэлдүүлж чадах уу? Ямар ч зүйлийг хийхэд мэргэн ухаан шаардагддаг гэж Би хэлдэг, гэтэл ямар нэг зүйлийг хийхдээ та нар Миний сануулгыг ахин дахин авч үзэж, тэдгээрт хайхрамжтай хандсан нь хэр олон билээ? Та нар Миний сануулгын нэг үгийг жаахан ойлгож, сонсох үедээ үүнийг сайн гэж боддог байлаа ч хожим нь үүнийг үл тоомсорлодог. Чи үүнийг сонсоод, өөрийн бодит нөхцөл байдал руу чиглүүлж, өөрийгөө үзэн яддаг, гэхдээ дараа нь үүнийг ялихгүй асуудал гэж боддог. Өнөөдөр, чиний амь өсөж чадах эсэх нь хамгийн чухал; гаднаа өөрийгөө яаж гоёж чимэх чинь чухал биш. Та нарын хэнд нь ч шийдэмгий байдал байдаггүй ба та нар шийдвэртэй байхыг хүсдэггүй, төлөөс төлөхийг хүсдэггүй, түр зуурын газар дэлхийн зугаа цэнгэлийг хаяхыг хүсдэггүй мөртөө тэнгэрийн ерөөлийг алдахаас айдаг. Энэ ямар төрлийн хүн бэ? Тэнэг хүн! Та нар гоморхох хэрэггүй; Миний хэлсэн зүйл баримттай биш гэж үү? Аль хэдийн бодсон зүйлийг чинь заан үзүүлсэн бус уу? Та нарт хүн чанар байхгүй! Та нарт хэвийн хүний шинж чанар ч байхгүй. Түүнчлэн, хэдий ийм байлаа ч та нар ядуу хоосон гэдгээ олж хардаггүй. Бүхэл өдөржин зав чөлөөтэй, хэнэггүй, туйлын сэтгэл хангалуун байдаг! Ямар их дутагдалтайгаа, эсвэл юу дутагдаж байгаагаа та нар мэддэггүй. Ямар мунхаг юм бэ!

Миний ажил хэдийнээ ийм цэгт хүрснийг та нар харахгүй байна гэж үү? Миний бүх хүсэл та нарт байгаа. Та нар хэзээ үүнийг ухаарч, хэзээ үүнд анхаарал хандуулах

юм бэ? Залхуу юм! Та нар төлөөс төлөхийг, шаргуу ажиллахыг, цаг гаргахыг болон хүчин чармайлт гаргахыг хүсдэггүй. Би чамд хэлье! Хүнд хэцүүг туулахаас айх тусам, амь чинь багахан ашиг тус хүртэнэ, түүнчлэн амь чинь өсөхийн хэрээр илүү их саад тотгортой учирч, амь чинь улам ахих янзгүй болдог. Би чамд дахин сануулъя (Би үүнийг дахиж хэлэхгүй)! Өөрийнхөө амийн төлөө хариуцлага үүрдэггүй хэнд ч Би хайхрамжгүй хандаж, орхих болно. Би үүнийг хэдийнээ хэрэгжүүлээд эхэлчихсэн; чи үүнийг тодорхой хараагүй гэж үү? Энэ нь бизнесийн хэлцэл ч биш, арилжаа наймаа ч биш; харин энэ бол амь. Ойлгомжтой юу?

52-Р БҮЛЭГ

Намайг зөвт байдлын Нар болон гарч ирэхэд та нар Надтай хамт алдар суу хийгээд сайн ерөөлийг үүрд мөнх хуваалцдаг! Энэ бол маргашгүй баримт бөгөөд аль хэдийн та нар дээр батлагдаад эхэлчихсэн. Учир нь Би амласан бүхнээ та нарт биелүүлнэ; Миний хэлдэг бүхэн бодит байдал бөгөөд хэзээ ч хий дэмий болохгүй. Эдгээр сайн ерөөл та нарт байна, өөр хэн ч үүнийг авч чадахгүй; энэ бол эв эетэйгээр Надтай харилцан уялдаж хийсэн үйлчлэлийн чинь үр шим юм. Шашны үзлээ хаяцгаа; Миний үгийн үнэн зөвд итгэ, бүү эргэлз! Би та нартай тоглоогүй байна, Би үнэнээсээ хэлсэн; Миний ерөөл хайрласан хүмүүс тийнхүү тэр ерөөлийг хүлээн авдаг бол Миний ерөөл хайрлаагүй хүмүүс ямар ч ерөөл хүлээн авдаггүй. Энэ бүхнийг Би тодорхойлдог. Газар дэлхийн эд баялаг ердөө л шалихгүй юм! Миний бодлоор бол энэ нь нэг центийн ч үнэ хүрэхгүй өтөг бууцнаас өөрцгүй. Тийм учраас та нар газар дэлхийн зугаа цэнгэлийг хэтэрхий өндрөөр үнэлэх хэрэггүй. Надтай хамт тэнгэрлэг ерөөл эдлэх нь хавьгүй илүү утга учиртай, үнэ цэнтэй биш гэж үү?

Урьд нь үнэн илчлэгдээгүй, Би ил тод гарч ирээгүй байсан; тэр үед та нар Надад эргэлзэж, Миний талаар итгэлтэй байж зүрхлээгүй. Харин одоо бүх зүйл илчлэгдэж, Би зөвт байдлын Нар болон гарч ирсэн билээ—тиймээс хэрвээ та нар эргэлзсээр байгаа бол тэрийгээ юу гэж хэлэх вэ? Газар дэлхийг харанхуй нөмөрсөн байх үед гэрлийг харж чадаагүйг чинь уучилж болно, харин одоо харанхуй булан тохой бүрийг нар гэрэлтүүлж, далд зүйл далд байхаа больж, нууц зүйл нууц байхаа больсон—хэрвээ та нар эргэлзсээр байгаа бол та нарыг Би тийм ч амархан өршөөхгүй! Одоо бол та нар Миний талаар туйлын итгэлтэй болж, Надад өөрсдийгөө зориулж, Миний төлөө зарлагадах цаг. Намайг өчүүхэн төдий эсэргүүцсэн хэнийг ч дахин бодож үзэхгүйгээр, хором ч хойшлуулахгүйгээр нэн даруй шүүлтийн галаар ниргэх болно—учир нь одоо бол өршөөлгүй шүүлт ирсэн үе, оюун санаа болоод зүрх сэтгэл нь зөв биш хүмүүст шүүлт тэр даруй ирнэ. Энэ бол “Миний ажил цахилах аянга мэт байдаг” хэмээн ярьдгийн жинхэнэ утга учир юм.

Энэ нь хурдан урагшилж байгаа; хүмүүсийг гайхшируулж, хүмүүсийг айдаст автуулахгүй байж чаддаггүй, үүнийг цаашид хойшлуулж, зогсоох боломжгүй. Миний ажлыг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, төдий чинээ хурдан урагшилна; сэрэмжгүй, бэлдээгүй хэн боловч үргэлж хөсөр хаягдах аюулд байдаг. Чи цаашид уруу таталтад автаж болохгүй. Миний ажил бүрэн эхэлж, Харь үндэстнүүд болон орчлон ертөнц даяар тэлж байна. Шүүлтийн гал харгис бөгөөд хэнийг ч өршөөж, хайрлахгүй. Бурханд үнэнч атлаа буруу бодол, санаа тээдэг, эсвэл ердөө л бага зэрэг эсэргүүцдэг хүмүүс бас шүүгдэх болно; үүнд эргэлзэх зүйлгүй. Миний гэрэл туссан хэн ч гэрэл дотор амьдарч, гэрэлд үйлдэж, замын төгсгөл хүртэл Надад үйлчилнэ. Гэрлийн дотор амьдардаггүй хүмүүс харанхуйд амьдарч байгаа. Тэднийг гэм буруудаа хандах хандлагаас нь хамаарч шүүснийхээ дараа Би шийдвэр гаргана.

Миний өдөр ирлээ. Өнгөрсөнд дурдсан “Миний өдөр” одоо нүдний чинь өмнө байна, учир нь та нар Надтай хамт буусан билээ. Би чамтай, чи Надтай; бид агаарт уулзсан, алдрыг хамтдаа хуваалцдаг. Миний өдөр үнэхээр бүрмөсөн ирчхээд байна!

53-Р БҮЛЭГ

Би бол Эхлэл, Би бол Төгсгөл. Би бол ахин амилсан, бүрэн төгс, цор ганц жинхэнэ Бурхан. Би та нарын өмнө Өөрийнхөө үгийг ярьдаг, харин та нар Миний хэлсэнд бат итгэх ёстой. Тэнгэр, газар нуран одовч Миний хэлж байгаа зүйлээс нэг үсэг, эсвэл нэг зураас ч алга болохгүй. Үүнийг сана! Үүнийг сана! Би айлдсаныхаа дараа нэг ч үгээ хэзээ ч буцааж байгаагүй бөгөөд үг нэг бүр биелэх болно. Одоо цаг нь ирсэн тул та нар бодит байдалд хурдан орох ёстой. Цаг бага байна. Би хөвгүүдээ алдар суутай хаанчлал руу хөтлөх ба ингэж та нарын тэмүүлж, эгээрэн хүсэж байсан бүхэн биелнэ. Миний хөвгүүд ээ! Хурдхан босож, Намайг дага! Та нарт эргэцүүлж бодоод л байх цаг алга. Алдсан цаг хэзээ ч эргэж ирэхгүй; харанхуйн дараа гэрэл байдаг бөгөөд өргөгдөх нь нүдний чинь өмнө байна. Та нар ойлгож байна уу? Нүдээ нээцгээ! Хурдхан сэр! Одоо үр дүнгүй дэмий ярианд оролцох, эсвэл чуулган байгуулахад ашиг тусгүй аливаа зүйл хэлэх гэж өөр хоорондоо ярилцахыг та нарт зөвшөөрөхгүй. Юу чухал вэ гэвэл, ах, эгч нараа өөрийн бодит туршлагаар, эсвэл Бурханы өмнө хэрхэн гэрэлтүүлэгдэж, өөрийгөө мэдсэн тухай яриагаар хангах нь чухал юм. Үүгээр хангаж чаддаг хэн ч биеийн хэмжээтэй байх болно! Өнөө үед та нарын зарим нь аанай л эмээхгүй байсаар байгаа бөгөөд Намайг юу ч хэлсэн, эсвэл Миний санаа хэчнээн зовсон ч чи эмээдэггүй хэвээр л байдаг; хуучин төрх чинь өөрт нь жаахан ч хүрэхийг зөвшөөрдөггүй. За, яах вэ, энэ маягаараа явж л бай! Зүгээр хүлээ, хэн сүйрэхийг хар! Чи үргэлж хорвоогоос шүүрч авах тухай бодож, эд хөрөнгөнд хорхойсож,

хөвгүүд, охид, нөхөртөө ихэд хоргоддог. За яах вэ, чи хоргодож л бай! Би та нарт юу ч хэлээгүй юм шиг, та нар ингэж дураараа дургиж л бай! Ойрын ирээдүйд, та нар бүхнийг ойлгох боловч тэр үед хэдийн оройтсон байна. Та нарыг зөвхөн шүүлт л хүлээж байна.

54-Р БҮЛЭГ

Чуулган бүрийг Би гарын арван хуруу шигээ мэддэг. Намайг тэдгээрийн талаар тодорхой ойлгодоггүй, сайн мэдэхгүй гэж бүү бод. Харин чуулгануудын олон янзын хүний тухайд Би бүр ч илүү сайн ойлголт, мэдлэгтэй. Илүү хурдан өсөж насанд хүрээсэй гэсэндээ чамайг сургахыг Би одоо яаран хүсдэг; тэгвэл чи Надад хэрэг болох өдөр илүү хурдан ирж магад; тэгснээр та нарын үйлдэл Миний мэргэн ухаанаар дүүрэн байж, Бурханыг хүссэн газраа илрүүлж чадна. Ийм маягаар Миний туйлын зорилго биелнэ. Хөвгүүд минь! Та нар Миний хүсэлд санаа тавих ёстой. Та нарт зааж байхдаа гарыг чинь барихад Намайг бүү хүргэ. Та нар Миний хүслийг ухаж ойлгон, хэрэг явдлын голыг нь олж харж сурах хэрэгтэй. Ингэвэл та нарт таарсан хэрэг явдал бүрийг хялбархнаар, хуруугаа инчдэх төдийд зохицуулж чаддаг болно. Сургалтдаа та нар эхний удаад ухаж ойлгохгүй байж магадгүй, харин хоёр дахь удаа, гурав дахь удаад гэх мэтээр эцэст нь та нар Миний хүслийг ухаж ойлгож чадна.

Та нарын үгэнд үргэлж ойлгогдошгүй чанар байдаг. Үүнийг та нар мэргэн ухаан гэж боддог, үгүй гэж үү? Заримдаа үг чинь дуулгаваргүй; зарим үед тоглоом шоглоом хийдэг; заримдаа хүний үзлээр, атаархаж жөтөөрхсөн шинжтэй ярьдаг… Дүгнэж хэлбэл, та нар туйлбаргүй ярьдаг, бусдыг хэрхэн амиар хангахыг, эсвэл тэдний нөхцөл байдлыг хэрхэн ойлгохыг мэддэггүй, харин ч хайнга ярьдаг. Та нарын бодол тодорхой бус, мэргэн ухаан гэж юу болох, ов мэх гэж юу болохыг мэддэггүй. Та нар ямар мунгинуу юм бэ! Та нар ов мэх, шударга бус занг мэргэн ухаан гэж үздэг; энэ нь Миний нэрийг шившиглэхгүй гэж үү? Энэ нь Намайг доромжлохгүй гэж үү? Энэ нь Намайг хилсдүүлэхгүй гэж үү? Тэгвэл эрж хайдаг зорилго чинь юу вэ? Та нар энэ тухай сайтар бодсон уу? Та нар энэ асуудлыг эрж хайсан уу? Би чамд хэлье, Миний хүсэл бол та нарын эрж хайдаг чиглэл, зорилго мөн. Тийм биш байсан бол бүгд хий дэмий болно. Миний хүслийг мэддэггүй хүмүүс бол хэрхэн эрж хайхыг мэддэггүй, орхигдож, таягдан хаягдах хүмүүс юм! Мэдээж, Миний хүслийг ухаж ойлгох нь та нарын сурах ёстой нэг дэх хичээл. Энэ бол хамгийн яаралтай даалгавар, хойшлуулж үл болно! Та нарыг нэг бүрчлэн зэмлэхийг минь битгий хүлээ! Та нар өдөржингөө хөшүүн, мулгуу униартсан байдалд өнгөрүүлдэг. Ямар хөгийн юм бэ! Та нарын мунгинуу байдал чинь гайхмаар юм; Миний хүсэлд та нар санаа тавьдаггүй! Өөрсдөөсөө асуу: үйлдэл хийхдээ та нар Миний хүслийг хэдэн удаа ухаж ойлгож байсан бэ? Та нар өөрсдийгөө сургах цаг чинь одоо болсон! Би та

нартай нэг нэгээр чинь харьцах боломжгүй! Та нар үйлдэнгээ туршлагажиж, мэдлэг ухаан, мэргэн ухаан олж авч сурах хэрэгтэй. Та нарын амнаас гарч байгаа үг сайн, сайхан боловч бодит нөхцөл байдал ямар байна? Та нар бодит байдалтай нүүр тулахдаа юу ч хийж чаддаггүй. Та нарын хэлдэг зүйл бодит байдалтай хэзээ ч нийцдэггүй. Би та нарын хийж байгаа зүйлийг үнэхээр харж тэвчдэггүй; Би ажиглах үедээ маш ихээр гуниглах сэтгэл төрдөг. Үүнийг сана! Ирээдүйд Миний хүслийг ухаж ойлгож сурцгаа!

55-Р БҮЛЭГ

Хэвийн хүн чанар гээч нь хүмүүсийн төсөөлдөг шиг ер бусын биш. Харин ч энэ нь бүх хүн, үйл явдал, эд зүйлсийн хүлээс, хүрээлэн буй орчноос үүсэн гарах хавчлагыг даван гарч чадна. Мөн ямар ч газар, ямар ч нөхцөл байдалд Надад ойртож, Надтай ярилцаж чаддаг. Хүмүүс та нар Миний санаа зорилгыг үргэлж буруу тайлбарладаг. Хэвийн хүн чанарыг амьдран харуулах хэрэгтэй гэж Намайг хэлэхэд та нар биеэ барьж, махан биеэ номхотгодог боловч сүнсэн дотроо анхааралтай хайхад ямар ч анхаарал хандуулдаггүй. Та нар зөвхөн гадаад байдалдаа л анхаарч, дотор чинь Миний хийж буй илчлэл болон сэтгэл хөдлөлийг үл тоодог. Ямар хайхрамжгүй юм бэ! Хэтэрхий хайхрамжгүй юм! Миний даалгасан зүйлийг гүйцэлдүүлэх нь агуу амжилт гэж чи үздэг юм гэж үү? Чи мунхаг юм! Чи үндэс сууриа гүн тавихад анхаарал хандуулахгүй байна! “Модны навч биш, харин үндэс нь бай”—чиний уриа энэ үнэхээр мөн үү? Бодлогогүй юм! Хайхрамжгүй юм! Жаахан зүйл олж авсан гэж бодмогцоо чи сэтгэл ханадаг. Чи Миний хүсэлд ямар бага санаа тавина вэ! Одоогоос эхлээд анхааралтай бай, идэвхгүй бүү бай, сөрөг бүү бай! Үйлчилж байхдаа чи Надад илүү олон удаа ойртож, Надтай илүү их ярилц: Энэ бол чиний цорын ганц гарц. Чи аль хэдийнээ өөрийгөө үгүйсгэснийг, өөрийн дутагдал болон сул талыг мэддэгийг Би мэднэ. Гэхдээ зүгээр нэг мэдэх нь хангалттай биш. Чи Надтай хамтран ажиллах хэрэгтэй бөгөөд Миний санаа зорилгыг ойлгосон даруйдаа нэн даруй хэрэгжүүл. Энэ бол, Миний ачаанд санаа тавих хамгийн сайн замаас гадна захирагдах хамгийн сайн зам.

Чи Надад яаж ч хандсан бай, чамд болон бүх ариун хүнд Би хүслээ гүйцэлдүүлэхийг хүсдэг бөгөөд бүх газар нутаг даяар саадгүй гүйцэлдээсэй гэж хүсдэг. Үүнийг сайн мэдэж бай! Энэ нь Миний захиргааны зарлигтай холбоотой! Чи өчүүхэн ч айхгүй байна уу? Чи өөрийн үйлдэл, зан авирын талаар айн дагжихгүй байна уу? Бүх ариун хүний дунд Миний санаа зорилгыг мэдэрч чаддаг хүн бараг алга. Чи Миний хүсэлд бүрэн анхаардаг хүн байж, бусдаас онцгойрохыг хүсэхгүй байна уу? Чи мэддэг үү? Миний яг одоогийн яаралтай санаа зорилго гэвэл Миний хүслийг бүрэн анхаарч чаддаг бүлэг хүнийг хайж олох явдал. Чи тэдний нэг баймааргүй байна уу? Чи Миний төлөө өөрийгөө зарлагадаж, Миний төлөө

өөрийгөө өргөн барихыг хүсэхгүй байна уу? Чи хамгийн бага ч гэсэн төлөөс төлөхийг ч, өчүүхэн ч гэсэн хичээл зүтгэл гаргахыг ч хүсдэггүй! Байдал энэ хэвээр үргэлжилбэл Миний уйгагүй зүтгэл та нар дээр талаар өнгөрнө. Үүнийг Би чамд хэлсэн байтал чи энэ асуудлын ноцтой байдлыг ойлгоогүй л байна уу?

“Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүмүүсийг Би асар ихээр ерөөх нь гарцаагүй.” Ойлгов уу! Би чамд үүнийг хэд хэдэн удаа хэлсэн хэр нь одоо ч гэсэн гэр бүлийн чинь нөхцөл байдал, гадаад орчинтой холбоотой өчнөөн болгоомжлол, айдас чамд байдаг. Чамд юу нь сайныг чи үнэндээ мэддэггүй! Үнэнч, энгийн, нээлттэй хүмүүсийг л Би ашигладаг. Чи аз жаргалтай, Надаар ашиглуулахыг хүссээр ирсэн, гэхдээ яагаад ингэж их санаа зовсоор байна вэ? Миний үг чамд ямар ч үр нөлөө үзүүлээгүй юм гэж үү? Би чамайг ашиглаж байгаа гэж хэлсэн, гэсэн ч чи үүнд тууштай итгэлтэй байж чаддаггүй. Чи үргэлж эргэлзэж, Надад хаягдахаас айдаг. Чиний үзэл үнэхээр гүн суусан! Би чамайг ашиглаж байна гэж хэлсэн л бол Би чамайг ашиглаж байна гэсэн үг. Чи яагаад байнга ингэж эргэлздэг юм бэ? Би хангалттай тодорхой яриагүй юм гэж үү? Миний хэлсэн үг бүр үнэн; худал айлдвар нэг ч байхгүй. Хүү минь! Надад итгэ. Надад чин сэтгэлээсээ ханд, тэгвэл Би чамд гарцаагүй чин сэтгэлээсээ хандана!

56-Р БҮЛЭГ

Мууг үйлддэг, эрх мэдэл эзэмшдэг ба Бурханы хөвгүүдийг хавчдаг хүмүүсийг шийтгэх арга хэмжээг Би аваад эхэлчихсэн. Одоогоос эхлээд, Миний захиргааны зарлигийн гар зүрх сэтгэлдээ Надтай зөрчилддөг хүмүүс дээр байх болно. Үүнийг мэд! Энэ бол Миний шүүлтийн эхлэл бөгөөд Би зөвт байдлыг хэрэгжүүлдэг, алагчилж үздэггүй Бурхан тул хэнд ч өршөөл үзүүлэхгүй, хэнийг ч хэлтрүүлэхгүй; үүнийг мэдэх нь та нарт сайн.

Мууг үйлддэг хүмүүсийг Би шийтгэхийг хүсдэг юм биш; харин тэд өөрсдийн муу үйлдлээс болж өөрсдөдөө залхаан цээрлүүлэлт авчирдаг. Би хэнийг ч шийтгэх гэж яардаггүй, бас хэнд ч шударга бус ханддаггүй—Би бүгдэд зөвт байдаг. Би хөвгүүдээ үнэхээр хайрладаг ба Намайг эсэргүүцдэг тэр муу хүмүүсийг үнэхээр үзэн яддаг; энэ бол Миний үйлдлүүдийн ар дахь зарчим. Та нар дор бүрнээ Миний захиргааны зарлигийн талаар жаахан ойлголттой байх хэрэгтэй; эс бөгөөс та нар өчүүхэн төдий ч эмээхгүй бөгөөд Миний өмнө хайхрамжгүй авирлах болно. Би юу гүйцэлдүүлмээр байгааг, юу биелүүлмээр байгааг, юу олж авмаар байгааг юм уу, эсвэл Миний хаанчлалд ямар төрлийн хүн хэрэгтэй гэдгийг та нар бас мэдэхгүй.

Миний захиргааны зарлиг бол:

1. Хэн байх чинь хамаагүй, зүрх сэтгэлдээ Надтай зөрчилдвөл чи шүүгдэнэ.
2. Миний сонгосон хүмүүс аливаа буруу бодлынхоо төлөө нэн даруй сахилга-жуулагдана.

3. Надад үл итгэгчдийг Би нэг тийш тавина. Хайхрамжгүй ярьж, үйлдэхийг нь Би тэдэнд эцсийг нь хүртэл зөвшөөрнө, тэгээд тэднийг бүрэн шийтгэж, учрыг нь олно.
4. Надад итгэгчдийг Би цаг ямагт харж хандан, хамгаална. Би авралын замыг ашиглан тэднийг цаг ямагт амиар хангана. Энэ хүмүүст Миний хайр байх бөгөөд тэд лав унахгүй, замаа алдахгүй. Тэдэнд буй аливаа сул тал түр зуурынх байх бөгөөд Би тэдний сул талыг мэдээж нэхэн санахгүй.
5. Надад итгэдэг мэт харагддаг ч үнэндээ итгэдэггүй—Бурхан байдагт итгэдэг боловч Христийг эрж хайдаггүй, гэхдээ бас эсэргүүцдэггүй—хүмүүс бол хамгийн өрөвдөлтэй бөгөөд Би Өөрийн үйл хэргээр дамжуулан тэдэнд тодорхой харуулна. Ийм хүмүүсийг Би үйлдлээрээ аварч, тэднийг буцаан авчирна.
6. Миний нэрийг эхлээд хүлээн зөвшөөрсөн, ууган хөвгүүд ерөөгдөнө! Би та нарыг ханатлаа эдлэг гэж хамгийн сайн ерөөлийг та нарт гарцаагүй хайрлана; хэн ч үүнд саад болж зүрхлэхгүй. Энэ бүгдийг тэр чигт нь та нарт бэлтгэсэн, учир нь энэ бол Миний захиргааны зарлиг билээ.

Миний гар юу хийдгийг, зүрх сэтгэлд минь ямар бодол байдгийг та нар бүх талаас нь харж чаддаг байх хэрэгтэй. Бүгд та нарын төлөө байдаг биш гэж үү? Та нарын дундаас хэн Миний төлөө байдаг вэ? Та нар зүрх сэтгэл дэх бодлуудаа, хэлж байгаа үгсээ нягталж шинжилсэн үү? Эдгээр зүйлд та нар ухамсартайгаар хандсан уу? Будилуу! Замбараагүй! Ариун Сүнсний хязгаарлалтыг хүлээж авдаггүй! Би чиний дотор Өөрийн дуу хоолойг ахин дахин гаргасаар байгаа, гэвч ямар ч хариу үйлдэл байсангүй. Дүйнгэ байхаа боль! Чиний үүрэг бол Миний хүслийг ухаарах явдал; түүнээс гадна, энэ нь чиний орох ёстой зам. Чи мунгинасан, чамд гүн ойлголт алга, Би чамд юу гүйцэлдүүлмээр байгааг, чамаас юу олж авмаар байгааг чи тодорхой хардаггүй! Миний хүслийг ухаарахын тулд Надад ойртон ирж, Надтай илүү их нөхөрлөж эхлэх ёстой. Миний хүслийг ухаарч чадахгүй байгаагаа чи байнга хэлдэг; чи аль хэдийн өөрийн зүйлсээр дүүрчихсэн байхад Би чам дээр яаж ажиллаж чадах юм бэ? Чи санаачилга гаргаж, Миний өмнө ирдэггүй, харин зүгээр л идэвхгүй хүлээдэг. Би чамайг өт шиг гэж хэлдэг, гэвч гомдож, хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Энэ удаа чи босоод Надтай хамтран ажиллах хэрэгтэй! Бүү идэвхгүй бай! Тэр нь чиний амийг хойш татна. Идэвх санаачилгатай байх нь бусдад биш, чамд тустай. Чи одоо болтол үүнийг таньж, ойлгоогүй гэж үү? Миний хүсэл чиний дотор байнга илчлэгддэг. Чи ухаарсангүй юү? Чи яагаад үүнд хэзээ ч анхаарал хандуулаагүй юм бэ? Бас чи яагаад Миний хүслийг хэзээ ч ухаарч чадаагүй юм бэ? Миний хүслийг ухаарах нь чамд ямар ч ашиггүй юм гэж үү?

Чи Миний хүслийг бүх талаар анхааран үзэж чадна хэмээн Би найдаж байна, тэгснээр чиний дотор Би урагшлах зам, амрах орон гэртэй болж болох юм. Надад саад хийхээ боль, энэ чинь дэндүү нүнжиггүй юм! Чамд Миний үгийн талаар ямар ч ойлголт алга, чи тэдгээрт ямар ч хариу үйлдэл үзүүлдэггүй. Одоо цаг юу болсныг

хар—цаашид хүлээх боломжгүй! Хэрвээ чи Миний мөрийг ойрхон дагадаггүй бол хэтэрхий оройтно, тэр ч бүү хэл, үүнийгээ залруулж чадах ямар ч арга байхгүй болно!

57-Р БҮЛЭГ

Чи бодол, санаа бүрээ, үйлдэл болгоноо шалгаж үзсэн үү? Тэдгээрийн аль нь Миний хүсэлд нийцдэг, аль нь нийцдэггүйг тодорхой мэдэж байна уу? Чи үүнийг ялган таньж яавч чадахгүй! Чи яагаад Миний өмнө ирсэнгүй вэ? Чамд Би хэлээгүй болохоор уу, эсвэл өөр шалтгаанаар уу? Чи үүнийг мэдэх ёстой! Тоомсоргүй хүмүүс Миний хүслийг ухаарч, ямар нэгэн агуу гэрэлтүүлэлт юм уу илчлэл хүлээн авч яавч чадахгүй гэдгийг мэд.

Чуулган хоол тэжээл авч чаддаггүй, жинхэнэ нөхөрлөлөөр дутмаг байдгийн шалтгааныг чи олж мэдсэн үү? Үүнд хүргэсэн хүчин зүйлсийн хэчнээн нь чамтай хамаатайг чи мэдэх үү? Амиар хангаж, Миний дуу хоолойг гарга гэж Би чамд зааварчилсан. Чи эдгээр зүйлийг хийсэн үү? Ах эгч нарынхаа амийн ахиц дэвшлийг саатуулсандаа чи хариуцлага хүлээж чадах уу? Чи асуудлуудтай нүүр тулахаараа тайван, хянамгай байхын оронд түгшиж мэгдсээр ирсэн. Чи үнэхээр мэдлэггүй! Миний дуу хоолой ариун хүмүүст хүрэх ёстой. Ариун Сүнсний ажлыг бүү дар, алгуурлаж Намайг бүү саатуул; эдний аль нь ч, хэнд ч ашиг тус өгөхгүй. Чи бие ба оюун санаагаараа өөрийгөө Надад бүрэн зориулаасай гэж Би хүсдэг, тэгснээр бодол, санаа бүр чинь Миний төлөө байж, чи Миний бодол, санааг хуваалцаж, хийдэг бүхэн чинь өөрийнхөө төлөө биш, өнөөгийн хаанчлал ба Миний удирдлагын төлөө байх болно. Зөвхөн энэ л Миний зүрх сэтгэлийг хангалуун болгоно.

Миний хийсэн юу ч нотолгоогүй байдаггүй. Чи яагаад Намайг дуурайсангүй вэ? Чи хийдэг зүйлдээ яагаад нотолгоо хайсангүй вэ? Надаар өөр юу хэлүүлмээр байна? Би чамд сургахаар гараас чинь атгасан боловч чи сурч чадаагүй. Чи үнэхээр тэнэг! Бүхнийг цоо шинээр эхэлмээр байна уу? Бүү сэтгэлээр уна. Чи дахин нэгэнтээ биеэ барьж, ариун хүмүүсийн хамтын найдвар болон хүслийн өмнөөс өөрийгөө бүхэлд нь зориулах ёстой. “Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүмүүсийг Би асар ихээр ерөөх нь гарцаагүй” гэсэн үгийг сана.

Чи юу ч хийсэн замбараагүй биш, дэг журамтай байдлаар хийх ёстой. Ариун хүмүүсийн байдлыг гарын арван хуруу шигээ мэднэ гэж чи үнэхээр хэлж зүрхлэх үү? Эндээс харахад чамд мэргэн ухаан дутаж байна, чи энэ асуудлыг огтхон ч нухацтай авч үзээгүй, үүнд ямар ч хугацаа зарцуулаагүй. Хэрэв чи үүнд хамаг цагаа үнэхээр зарцуулж чадсан бол дотоод байдал чинь ямар байх байсныг харна. Чи бодитой хүчин чармайлт гаргахаар эрмэлздэггүй; зүгээр л бодит шалтгаануудыг хайж, Миний хүслийг өчүүхэн төдий ч анхаарч үздэггүй. Энэ нь Намайг гүнээ шархлуулсан! Ийм маягаар бүү үргэлжлүүл! Миний чамд өгсөн ерөөлүүдийг чи хүлээн авахгүй юм гэж үү?

Өө, Бурхан минь! Таны хүүхэд Танд өртэй билээ. Би Таны ажлыг ноцтойгоор авч үзээгүй, Таны хүсэлд анхаарал тавиагүй, Таны сургамжид ч итгэлтэй байгаагүй. Таны хүүхэд энэ бүхнийг өөрчлөхийг хүсэж байна. Та намайг орхихгүй байх болтугай, Та надаар дамжуулан Өөрийн ажлыг үргэлжлүүлэн хийх болтугай. Өө, Бурхан минь! Хүүхдээ ганцааранг нь бүү үлдээгээч! Харин хором мөч тутамд намайг дагалдаач. Өө, Бурхан минь! Намайг хайрладгийг тань Таны хүүхэд мэддэг ч би Таны хүслийг ухаарч чаддаггүй; Таны ачааг хэрхэн анхаарахаа мэддэггүй, эсвэл Таны даалгасан зүйлийг хэрхэн биелүүлэхээ мэддэггүй. Тэр ч бүү хэл чуулганыг хэрхэн хариулахаа мэддэггүй. Үүнд би гуниглаж, бачимдаж байгааг Та мэднэ. Өө, Бурхан минь! Цаг ямагт намайг залж чиглүүлээч. Одоо л би өөрийнхөө хэчнээн дутуу дулимгийг, бүр дэндүү дулимаг гэдгийг мэдэрч байна! Хэр их гэдгийг нь би дүрслэн хэлж ер чадахгүй нь. Таны төгс хүчит гар Өөрийн хүүхдэд нигүүлсэл үзүүлж, намайг цаг ямагт дэмжиж, Таны өмнө нүүрээрээ газар унан мөргөхийг зөвшөөрч, өөрийн сонголтыг хийдэггүй, өөрийн гэсэн бодол, санаатай байдаггүй болгож өгөөч. Өө, Бурхан минь! Таны хүүхэд бүх зүйлийг Таны төлөө, өнөөгийн хаанчлалын төлөө хийхийг хүсдэгийг Та мэднэ. Энэ цаг мөчид миний юу бодож байгааг, миний юу хийж байгааг Та мэднэ. Өө, Бурхан минь! Намайг Өөрөө шинжлэн шалгаач! Та амьдралын цаг тутамд надтай хамт алхаж, надтай хамт үлдээч гэж л би Танаас гуйя, ингэснээр Таны хүч чадал миний хийдэг бүхнийг дагалдах болно.

58-Р БҮЛЭГ

Миний санаа зорилгыг ухаараад чи Миний ачааг анхаарах чадвартай болно, мөн гэрэл гэгээ, илчлэл болон чөлөөлөлт, эрх чөлөөг олж авч чадна. Энэ нь Миний сэтгэлийг хангалуун болгож, чамд зориулсан Миний хүслийг хэрэгжүүлж, бүх ариун хүнийг босгон байгуулж, газар дээрх Миний хаанчлалыг бат бэх, тогтвортой болгоно. Одоо чухал зүйл нь Миний санаа зорилгыг ухаарах явдал юм; энэ бол та нарын орох ёстой зам, түүнчлэн хүн бүрийн гүйцэтгэх ёстой үүрэг юм.

Миний үг бол бүх төрлийн өвчнийг анагаадаг сайн эм. Миний өмнө ирэхийг хүсэж байгаа цагт Би чамайг эмчилж, Өөрийнхөө бүхнийг чадагч байдлыг, Өөрийнхөө гайхалтай үйл хэргийг, Өөрийнхөө зөвт байдал, сүр жавхланг харуулна. Түүнчлэн Би та нарт өөрсдийн чинь завхрал, сул дорой байдлыг хальт харуулна. Би чиний доторх нөхцөл байдал бүрийг бүрэн ойлгодог; чи үргэлж зүрх сэтгэл дотроо аливааг хийдэг ба гаднаа харуулдаггүй. Би чиний хийдэг юм болгоныг бүр ч тодорхой мэддэг. Гэхдээ Би ямар зүйлсийг магтаж, ямар зүйлсийг магтдаггүйг чи мэдэх ёстой; чи энэ хоёрыг тодорхой ялгах хэрэгтэй бөгөөд үүнд хайнга хандах ёсгүй.

“Бид Бурханы ачаанд анхаарал хандуулах ёстой” гэж хэлснээрээ чи зүгээр л дүр эсгэж байна. Харин баримтуудтай нүүр тулах үедээ чи Бурханы ачаа гэж юу

болохыг сайн мэддэг хэр нь ямар ч анхаарал хандуулдаггүй. Чи үнэхээр нэлээд будилуу, мунхаг, мөн түүнчлэн туйлын мэдлэггүй. Энэ нь хүмүүстэй харьцах хэчнээн хэцүү болохыг тайлбарладаг; тэд “Би зүгээр л Бурханы санаа зорилгыг ухаарч чадахгүй байна, гэхдээ үүнийг ухаарах юм бол мэдээжийн хэрэг үүнд нийцүүлэн үйлдэнэ” гэх мэт сайхан сонсогдох үг л хэлдэг. Энэ нь та нарын бодит нөхцөл байдал биш гэж үү? Хэдийгээр та нар бүгд Бурханы санаа зорилгыг мэддэг, өөрсдийнхөө өвчний шалтгааныг мэддэг ч гол асуудал бол та нар хэрэгжүүлэхийг огт хүсдэггүй; энэ нь хамгийн та нарын том бэрхшээл юм. Хэрвээ үүнийг даруйхан шийдвэрлэхгүй бол амийн чинь хамгийн том саад тотгор болох болно.

59-Р БҮЛЭГ

Чи тулгардаг орчноосоо Миний хүслийг илүү их эрж хай, тэгвэл Миний магтаалыг гарцаагүй хүртэнэ. Чи эрж хайж, Намайг хүндлэх хүсэлтэй байгаа цагт дутагддаг бүхнийг чинь Би чамд өгнө. Чуулган одоо албан ёсны сургалтад орж, бүх зүйл зөв замдаа орж байна. Юмс ирээдүйд болох зүйлсийн урьтал байхаа больсон; та нар цаашид будилж, эсвэл ялган таних чадваргүй байх ёсгүй. Яагаад Би та нараас, бүх зүйл дээр бодит байдал руу орохыг шаарддаг вэ? Чи үүнийг үнэхээр туулсан уу? Би та нарын хүслийг хангадаг шиг Миний шаарддаг зүйл дээр та нар үнэхээр Намайг сэтгэл хангалуун болгож чадах уу? Ов мэхтэй бүү бай! Би та нарыг ахин дахин тэвчсээр л байгаа хэр нь та нар сайн, муугийн ялгааг удаа дараа мэддэггүй, талархлаа илэрхийлж чаддаггүй!

Миний зөвт байдал, Миний сүр жавхлан, Миний шүүлт ба Миний хайр—Надад байгаа энэ бүх зүйл, Би юу болох зүйлсийг чи үнэхээр амталсан уу? Та нар үнэхээр маш бодлогогүй, мөн Миний хүслийг ойлгохгүй байхаар зүтгэдэг. Миний бэлтгэсэн зоогийг та нар өөрсдөө амтлах ёстой гэж Би ахин дахин хэлсэн, гэсэн ч та нар үүнийг удаа дараа түлхэн унагадаг ба сайн орчныг муугаас ялгаж чаддаггүй. Эдгээр орчноос алийг нь та нар өөрсдөө бий болгосон бэ? Алийг нь Миний гар зохицуулсан бэ? Өөрсдийгөө хамгаалахаа боль! Би бүх зүйлийг тов тодорхой хардаг, үнэн хэрэгтээ чи л эрж хайдаггүй. Би өөр юу хэлэх билээ?

Миний хүслийг ойлгодог бүх хүнийг Би үргэлж тайвшруулах ба зовж, хор хөнөөл амсахыг нь зөвшөөрөхгүй. Одоо гол зүйл бол Миний хүслийн дагуу үйлдэл хийж чаддаг байх явдал. Үүнийг хийдэг хүмүүс гарцаагүй Миний ерөөлийг хүртэж, Миний хамгаалалтад орно. Та нарын дундаас хэн өөрийгөө Миний төлөө үнэхээр, бүрмөсөн зарлагадаж, байгаа бүхнээ Миний төлөө өргөн барьж чадах вэ? Та нар шийдэмгий бус; бодол чинь гэр орон, гадаад ертөнц, хоол хүнс, хувцас хунараа бодож, тэдгээрийг тойрон эргэлддэг. Чи энд Миний өмнө байж, Миний төлөө аливааг хийж байгаа хэдий ч зүрх сэтгэлийнхээ гүнд гэрт буй эхнэр, хүүхдүүд, эцэг эхээ бодсоор байгаа. Энэ бүхэн чиний эд хөрөнгө мөн үү? Яагаад чи тэдгээрийг

Миний гарт даатгадаггүй юм бэ? Чи Надад хангалттай итгэдэггүй юм гэж үү? Эсвэл Би чамд тохиромжгүй зохицуулалт хийнэ гэж айж байна уу? Чи махан биеийнхээ гэр бүлд яагаад үргэлж санаа зовдог юм бэ? Чи хайртай хүмүүсээ үргэлж хүсэмжилдэг! Би чиний зүрх сэтгэлд тодорхой байр суурь эзэлдэг үү? Намайг өөрийнхөө дотор ноёрхуулж, Надаар бүх оршихуйгаа эзэмдүүлэх тухай чи ярьсаар байдаг ч эдгээр нь бүгд худал хуурмаг! Та нараас хэд чинь бүх зүрх сэтгэлээ чуулганы төлөө зориулдаг вэ? Та нарын дундаас хэн чинь өөрийгөө боддоггүй, харин өнөөдрийн хаанчлалын төлөө үйлдэж байна вэ? Энэ талаар маш анхааралтай бодоод үз.

Та нар Намайг ийм хэмжээнд түлхсэн учраас Би та нарыг идэвхжүүлэхийн тулд гараа л ашиглаж чадна; Би цаашид та нарыг аргадахгүй. Учир нь Би бол ухаалаг Бурхан бөгөөд Надад хэр үнэнч байгаагаас чинь хамааран Би өөр өөр хүмүүст өөр өөр арга замаар ханддаг. Би бол төгс хүчит Бурхан—хэн Миний урагшлах алхамд саад хийж зүрхлэх билээ? Одоогоос эхлээд, Надад үнэнч бус хандаж зүрхэлдэг бүх хүн Миний захиргааны зарлигийн гар дор гарцаагүй ирнэ, ингэснээр тэд Миний төгс хүчнийг мэднэ. Миний хүсдэг зүйл бол асар олон хүн биш, харин өндөр ур чадвар юм. Би үнэнч бус, шударга бус, гажууд зан авиртай, ов мэхтэй хэнийг ч бай орхиж, шийтгэх болно. Намайг өршөөнгүй гэж, эсвэл хайр энэрэлтэй агаад эелдэг гэж бодохоо боль; ийм бодол бол зүгээр л өөрийгөө өөгшүүлж байгаа хэрэг. Би чамайг өөгшүүлэх тусам чи улам сөрөг, идэвхгүй болж, өөрийгөө орхих хүсэлгүй болдог гэдгийг Би мэднэ. Хүмүүс ийм хэмжээнд хэцүү байх үед Би тэднийг байнга зоригжуулж, чирээд явж л чадна. Үүнийг мэдэж ав! Одоогоос эхлэн Би бол шүүдэг Бурхан; Би хүмүүсийн төсөөлдөг шиг өршөөнгүй, эелдэг, энэрэнгүй Бурхан байхаа больсон!

60-Р БҮЛЭГ

Амь өснө гэдэг хялбар зүйл биш; энэ нь үйл явцыг шаарддаг, түүнчлэн төлөөс төлж, нэгэн зүрх сэтгэлээр Надтай хамтран ажиллаж чаддаг байхыг та нараас шаарддаг бөгөөд тийнхүү та нар Миний магтаалыг хүртэнэ. Тэнгэрүүд, газар болон бүх зүйл Миний айлддаг үгээр байгуулагдаж, бүрэн төгс болгуулдаг ба Надтай хамт байхад юуг ч гүйцэлдүүлж болно. Та нар хурдан өсөж, Миний мөрнөөс ачаа авч, өөрсдийнхөө мөрөн дээр тавьж, Миний өмнөөс хөдөлмөрлөх нь Миний цорын ганц хүсэл юм; тэр үед л Би сэтгэл хангалуун болно. Ямар хүү эцгийнхээ ачаанаас татгалзах билээ? Ямар эцэг хүүгийнхээ төлөө өдөр, шөнөгүй хөдөлмөрлөхгүй байх билээ? Гэсэн ч та нар Миний хүслийг ер ойлгодоггүй, Миний ачаанд хайхрамжгүй ханддаг; Миний үг та нарт нөлөөлдөггүй, та нар Миний хэлснээр хийдэггүй. Та нар үргэлж өөрсдийнхөө эзэн байдаг; ямар хувиа хичээсэн юм бэ! Та нар зөвхөн өөрсдийгөө л боддог!

Чи үнэхээр Миний хүслийг ойлгодог уу, эсвэл ойлгодоггүй дүр эсгэж байна уу? Яагаад чи үргэлж ийм садар араншин гаргадаг юм бэ? Ингэж авирласнаараа Миний хувьд зөв зүйл хийж байгаа гэж мөс чанар чинь хэлж байна уу? Өвчний учир шалтгааныг олох үедээ чи эмчилгээнийх нь талаар яагаад Надтай ярьдаггүй юм бэ? Би чамд хэлье: Энэ өдрөөс эхлээд та нарын бие ямар ч өвчин тусахгүй. Хэрэв биеийн чинь аль нэгэн хэсэг сайнгүй санагдвал гадаад шалтгаан хайж цагаа бүү үр; харин Миний өмнө ирж, Миний санаа зорилгыг мэдэхээр хичээ. Үүнийг санаж явах уу? Энэ бол Миний амлалт: Энэ өдрөөс эхлээд та нар махан биеэсээ бүрмөсөн явж, сүнслэг ертөнцөд орно; өөрөөр хэлбэл, та нарын бие цаашид өвчинд нэрвэгдэхгүй. Үүнд сэтгэл чинь ханаж байна уу? Баяр баясгалантай байна уу? Энэ бол Миний амлалт. Цаашлаад та нарын удаан найдаж байсан зүйл. Өнөөдөр, ерөөгдсөн та нар дээр энэ нь биелдэг. Хэчнээн хэмжээлшгүй, гайхалтай билээ!

Миний ажил өдөр, шөнөгүй явагддаг; хором бүрд хэзээ ч зогсдоггүй. Яагаад гэвэл, Миний хойшлуулшгүй хүсэл бол чамайг Өөрийн зүрх сэтгэлийн дагуу болгох ба Миний зүрх сэтгэлийг та нар удалгүй тайтгаруулна. Миний хөвгүүд ээ! Миний сайны ерөөлөөс хуваалцах цаг чинь ирлээ! Өмнө нь та нар Миний нэрийн төлөө зовж шаналсан, харин одоо та нарын шалгалтын өдөр хоногууд дууслаа. Хэн нэгэн Миний хөвгүүдийн толгой дээрх ганц ширхэг үсэнд хор хөнөөл учруулж зүрхлэх аваас Би тэднийг амархан өршөөхгүй, мөн тэд хэзээ ч дахин өндийн босож чадахгүй. Энэ бол Миний захиргааны зарлиг, үүнийг зөрчсөн хэн ч өөрийгөө аюулд учруулна. Миний хөвгүүд ээ! Сэтгэлээ ханатал хөгжилд! Баярлан дуулж, хашхир! Та нар дээрэлхүүлэн, дарлагдахаа болино, хавчлагад өртөхөө болино. Надад итгэдгийнхээ төлөө та нар цаашид айх ёсгүй; итгэлээ ил тод зарлах ёстой. Орчлон ертөнц, газар дэлхийн зах хязгаарыг доргитол чангаар Миний ариун нэрийг дууд. Өөрсдийнх нь дорд үзэж, сүйтгэж, тамлаж байсан хүмүүс өнөөдөр дээр нь зогсож, тэднийг удирдаж, захирч, бүр шүүж байгааг тэдэнд харуул.

Та нар өөрсдийнхөө оролтод л анхаар, та нараар эдлүүлэх гэж хүлээсэн илүү дээр ерөөлүүдийг Би та нарт хайрлах бөгөөд та нар харьцуулшгүй жаргал, ойлгошгүй гүн гүнзгий байдал, дуусашгүй нууцыг нь илүү сайн мэдэрч чадна!

61-Р БҮЛЭГ

Чи өөрийнхөө нөхцөл байдлыг мэддэг байвал Миний хүслийг биелүүлж магад. Үнэндээ, Миний хүслийг ойлгох хэцүү биш; ердөө л өмнө нь чи хэзээ ч Миний санаа зорилгын дагуу эрж хайгаагүй. Хүмүүсийн үзэл, бодлыг Би хүсдэггүй, чиний мөнгө, өмч хөрөнгийг бол бүр ч үгүй. Миний хүсдэг зүйл бол чиний зүрх сэтгэл. Ойлгож байна уу? Энэ бол Миний хүсэл; үүнээс ч илүүтэйгээр энэ бол Миний олж авахыг хүсдэг зүйл юм. Хүмүүс үргэлж өөрсдийн үзлийг ашиглан Намайг шүүдэг, өөрсдийн шалгуурыг ашиглан Миний биеийн хэмжээг үнэлдэг. Хүн төрөлхтний хувьд

зохицуулахад хамгийн хэцүү зүйл нь энэ бөгөөд энэ бол Миний хамгийн их жигшиж, үзэн яддаг зүйл гэдгийг одоо та нар ойлгов уу? Яагаад гэвэл, энэ нь Сатаны хамгийн илэрхий зан чанар юм. Түүнчлэн, та нарын биеийн хэмжээ маш жаахан тул та нар байнга Сатаны зальт явуулгад автдаг. Та нар зүгээр л тэдгээрийг ялган таньж чадахгүй байна! Сатанд хууртахгүй байхын тулд цаг ямагт, бүх талаар болгоомжтой байгаарай гэж Би та нарт олон удаа хэлсэн. Гэсэн ч та нар Миний хэлснийг сонсохгүй, харин ч хэнэггүйхэн үл тоомсорлодог. Үүний улмаас амиараа хохирол амсаж, гэмшихэд хэтэрхий оройтдог. Үүнийг ирээдүйн эрэл хайгуулын чинь төлөөх сургамж гэж үзэх нь сайхан санаа биш гэж үү? Би чамд хэлье! Сөрөг болох хандлагатай байх нь аминд чинь туйлын ноцтой хохирол авчирна. Үүнийг мэдсэн болохоор сэрэх цаг чинь болсон бус уу?

Хүмүүс хурдан үр дүнд хүрэх гэж яардаг бөгөөд зөвхөн нүдний өмнө байгаа зүйлээ л хардаг. Би эрх мэдэлтнүүдийг шийтгэж эхэлсэн гэж хэлэхэд та нар улам их түгшиж, “Яагаад тэр хүмүүс эрх мэдэлтэй байсаар байгаа юм бэ? Энэ нь Бурханы үг хоосон гэсэн үг биш гэж үү?” хэмээн асуудаг. Хүний үзэл маш гүн суусан байдаг! Та нар Миний хэлдэг зүйлийн утга учрыг ойлгодоггүй. Миний шийтгэдэг хүмүүс бол муу хүмүүс, Намайг эсэргүүцдэг, Намайг мэддэггүй хүмүүс бөгөөд үнэнийг эрж хайлгүйгээр Надад итгэх төдий болдог хүмүүсийг Би үл тоодог. Та нар үнэхээр мэдлэггүй! Та нар Миний хэлсэн зүйлийн өчүүхэн хэсгийг ч ойлгоогүй! Ийм байхад ч гэсэн та нар өөрсдийгөө сайшааж, өөрсдийгөө төлөвшсөн, аливааг ойлгодог, Миний хүслийг ойлгох чадвартай болсон гэж бодсоор байдаг. Бүх зүйл, хэрэг явдал Христэд үйлчлэл үзүүлдэг гэж Би байнга хэлдэг боловч чи жинхэнээсээ эдгээр үгийг ойлгодог уу? Тэдгээр нь ямар утгатай болохыг чи мэдэх үү? Хэнийг ч яаран шүүдэггүй гэдгээ Би өмнө нь хэлсэн. Орчлон ертөнцийн хүн нэг бүр Миний зүй зохистой зохицуулалтыг дагадаг. Миний шийтгэлийн бай болсон, Христэд үйлчлэл үзүүлдэг хүмүүс (тэднийг Би аврахгүй), Миний сонгосон хүмүүс, мөн Би сонгосон боловч дараа нь таягдан хаягдах хүмүүс—энэ бүгдийг Би гартаа атгадаг, Миний бүр илүү сайн ойлгодог сонгогдсон хүмүүсийн нэг болох чамайг хэлэхийн ч хэрэггүй. Энэ болон дараагийн шатанд Миний хийдэг бүх зүйл, Миний ухаалаг зохицуулалтад нийцдэг. Чи Надад зориулан урьдаас зохицуулалт хийх хэрэггүй; зүгээр л хүлээж байгаад таашаа! Энэ бол чиний хүртэх ёстой зүйл. Би Өөрийн гэсэн зүйлсийг ноёрхдог бөгөөд гомдоллож зүрхэлдэг, Миний талаар өөр үзэл бодолтой хүмүүсийг амархан зүгээр өнгөрөөдөггүй. Миний зохицуулсан захиргааны зарлигийн хөтөлбөр энэ үе шатанд хүрсэн тул энэ өдрүүдэд Миний уур хилэн байнга дүрэлздэг. Намайг ямар ч сэтгэл хөдлөлгүй гэж бүү бод. Яагаад гэвэл нэг ч эд зүйл, хүн, үйл явдал урагшлах алхамд минь саад хийж зүрхлэхгүй гэж Би өмнө нь хэлсэн. Би хэлснээ хийдэг, энэ бол Би; түүнчлэн энэ нь Миний зан чанарын хамгийн тод илрэл юм. Та нар бүгд Миний хөвгүүд тул бүх хүнтэй Би адил тэгш харьцаж, бүгдийг нь хайрладаг. Ямар эцэг хүүгийнхээ амьдралд хариуцлага хүлээхгүй байх билээ? Ямар эцэг хүүгийнхээ ирээдүйн төлөө өдөр шөнөгүй шаргуу ажиллахгүй байх билээ? Та нарын дундаас хэн үүнийг хүлээн

зөвшөөрч байна вэ? Хэн Миний зүрх сэтгэлд санаа тавьж чадах вэ? Та нар байнга өөрсдийн бие махбодын таашаалын төлөө төлөвлөж, зохицуулалт хийдэг бөгөөд Миний зүрх сэтгэлийг огт ухаардаггүй. Би бүх зүрх сэтгэлээрээ та нарын төлөө санаа зовдог хэдий ч та нар бие махбодын таашаал, идэх, уух, унтах, өмсөх хувцас хүсэн мөрөөддөг. Та нарт жаахан ч гэсэн мөс чанар алга уу? Хэрэв ийм бол та нар хүний арьс нөмөрсөн араатнууд юм. Миний хэлсэн зүйл зохисгүй биш бөгөөд та нар эдгээр үгийг даах чадвартай байх ёстой. Энэ бол та нарыг аврах хамгийн сайн арга, үүнээс ч илүүтэйгээр Сатаны амин газрыг цохиж, түүнийг бүрэн ялж, бүрмөсөн устгах Миний мэргэн ухаан энд оршдог. Чи гэмшиж, мөн хуучин уг чанараа таягдан хаяж, шинэ хүний дүр төрхийг амьдран харуулахын тулд Надад баттай найдах аваас энэ нь хэвийн хүн чанарыг амьдран харуулж, Миний нэрийг гэрчилж байгаа хэрэг тул Би бүрэн сэтгэл ханана. Юу ч Намайг үүнээс илүү аз жаргалтай болгохгүй.

Чи үргэлж Надтай ойр байх ёстой. Миний алхаа өдрөөс өдөрт улам түргэсэж байгаа нь илэрхий байна. Хэрэв чамд нэг хором ч гэсэн сүнслэг нөхөрлөл дутагдвал Миний шүүлт тэр даруй чам дээр бууна. Энэ үед чи гүнзгий ухаарал олж авсан байна. Би чамд хайргүй учраас чамайг цээрлүүлдэг юм биш; харин ч чамайг хайрласандаа сахилгажуулж байгаа юм. Эс тэгвээс чи өсөхгүй, Ариун Сүнсний хязгаарлалт байхгүй бол үргэлж завхай зайдан байх болно. Энэ нь Миний мэргэн ухааныг улам харуулж байна.

62-Р БҮЛЭГ

Миний хүслийг ухаарах нь зөвхөн мэдэхийн төлөө биш, харин Миний санаа зорилгын дагуу үйлдэхийн төлөө байдаг. Хүмүүс Миний зүрх сэтгэлийг ер ойлгодоггүй. Намайг зүүн зүг гэж хэлэхэд тэд өөрийн эрхгүй нягтлан бодож, “Энэ үнэхээр зүүн зүг үү? Биш ч байж магадгүй. Би үүнд зүгээр л итгэж болохгүй; өөрөө харах хэрэгтэй” гэж гайхширдаг. Хүмүүс та нартай харилцахад ийм хэцүү; жинхэнэ дуулгавартай байдал гэж юу болохыг та нар мэддэггүй. Миний санаа зорилгыг мэдэх үедээ зүгээр л хэрэгжүүлэхэд анхаар—битгий бод! Чи Миний хэлсэнд үргэлж итгэж яддаг ба утгагүй байдлаар хүлээж авдаг. Ийм байж яаж жинхэнэ мэдлэг ухаантай болж чадах юм бэ? Чи хэзээ ч Миний үг рүү ордогүй. Өмнө нь хэлсэнчлэн, Би асар олон тооны хүнийг биш, хүмүүсийн давуу чанарыг л хүсдэг. Миний үг рүү ороход анхаардаггүй хэн боловч Христийн сайн цэрэг байхад тохирохгүй; харин тэд Сатаны зарц мэт авирлаж, Миний ажлыг үймүүлдэг. Үүнийг жижиг асуудал гэж бүү бод. Миний ажлыг үймүүлж, Миний захиргааны зарлигийг зөрчдөг хэн ч бай, Би тийм хүмүүсийг хатуу сахилгажуулах нь лавтай. Өөрөөр хэлбэл, одоогоос эхлээд чи Надаас хормын төдий нүүр буруулах аваас шүүлт чам дээр бууна. Хэрвээ Миний үгэнд итгэхгүй бол Миний нүүр царайн гэрэлд амьдрах ямар байдгийг, Намайг орхиход ямар байдгийг өөрөө хар.

Чамайг сүнс дотор амьдардаггүй гэдэгт Миний санаа зовдоггүй. Миний ажил одоогийн үе шат хүртэл ахисан, тэгвэл чи юу хийж чадах вэ? Бүү санаа зов, учир нь Миний хийдэг бүхэнд алхам байдаг бөгөөд Би ажлаа Өөрөө хийнэ. Намайг ямар нэгэн зүйл хийхэд бүгд бүрэн үнэмшдэг; эс тэгвээс Би хоёр дахин хатуу гэсгээнэ, энэ нь цаашлаад Миний захиргааны зарлигийг хөнддөг. Миний захиргааны зарлиг хойшид нууц байхаа болж, аль хэдийн тунхаглагдаж, хэрэгжиж эхэлснийг харж болно. Чи үүнийг тодорхой харах ёстой! Одоо бүх зүйл Миний захиргааны зарлигт хамаатай бөгөөд тэдгээрийг зөрчсөн хэн ч хохирол амсах ёстой. Энэ нь ялихгүй асуудал биш. Та нар үүнийг үнэхээр нарийн мэдэж байна уу? Тодорхой харж байна уу? Би нөхөрлөж эхэлнэ: Дэлхийн бүх улс үндэстэн, бүх ард түмэн Миний гарт захирагддаг бөгөөд шашин шүтлэгээсээ үл хамааран тэд Миний сэнтий рүү буцан ирэх ёстой. Мэдээж, шүүлт туулсан зарим хүн ёроолгүй нүхэнд хаягдана (бүрмөсөн шатаад, цаашид үлдэхгүй сүйрлийн бай болно), харин шүүгдсэнийхээ дараа Миний нэрийг хүлээн авах зарим хүн Миний хаанчлалын ардууд болно (тэд мянган жил л үүнийг эдэлнэ). Гэхдээ та нар Надтай хамт мөнхөд хаанчлах бөгөөд урьд нь та нар Миний төлөө зовсон тул Би эцэс төгсгөлгүй та нарт хүртээх ерөөлөөрөө зовлонг чинь орлуулна; Миний ардууд ердөө Христэд үйлчлэл үзүүлсэн хэвээр байна. Энд буй баяр хөөр гэдэг нь зөвхөн баяр хөөрийг хэлдэг бус, харин тэр хүмүүс гамшиг амсахгүй байхыг хэлнэ. Энэ бол та нарт тавьдаг Миний шаардлага одоо ийм хатуу байгаагийн, мөн одоо бүх зүйл Миний захиргааны зарлигт хамаатай байдгийн дотоод утга учир юм. Учир нь, хэрвээ та нар Миний сургалтыг хүлээн аваагүй бол Би өвлөж авах учиртай зүйлийг чинь та нарт өгөх аргагүй байх байлаа. Хэдий тийм боловч та нар зовж шаналахаас айж, сүнс чинь шархлахаас эмээсээр, махан биеэ үргэлж бодож, өөрийнхөө төлөө байнга зохицуулалт хийж, төлөвлөдөг. Та нарт зориулсан Миний зохицуулалт тохиромжтой биш гэж үү? Тэгвэл чи яагаад өөртөө зохицуулалт хийсээр л байдаг юм бэ? Чи Намайг гутаадаг! Тийм биш гэж үү? Би чамд зориулж ямар нэгэн зүйл зохицуулдаг, гэтэл чи үүнээс бүрэн татгалзаж, өөрийнхөө төлөвлөгөөг гаргадаг.

Та нар уран цэцэн үгтэй байж магадгүй боловч үнэн хэрэгтээ Миний хүслийг огт анзаардаггүй. Намайг сонс! Та нарын дунд Миний хүслийг чин сэтгэлээсээ анхаарах чадвартай хүн байгаа гэж Би яавч хэлэхгүй. Үйлдэл чинь Миний хүсэлд нийцэж магадгүй ч Би чамайг мэдээж магтахгүй. Энэ бол Миний авралын арга барил юм. Тэгсэн ч гэсэн, та нар заримдаа мөн л бардамнасаар, өөрсдийгөө гайхалтай хэмээн бодож, бусдыг басамжилдаг. Энэ бол хүний ялзарсан зан чанарын нэг тал юм. Та нар бүгд Миний хэлж байгаа зүйлийг өнгөцхөн хүлээн зөвшөөрдөг. Үнэхээр өөрчлөгдөж чадахын тулд та нар Надад ойртох хэрэгтэй; Надтай нөхөрлө, Би чамд нигүүлсэл хайрлана. Зарим хүн зүгээр л биеэ оторлож, бусдын тарьсныг хураахыг хүсэж, хувцаслуулахын тулд гараа сунгаж, тэжээлгэхийн тулд амаа ангайх хэрэгтэй гэж л бодон, тэр ч байтугай, бусад хүмүүс хоолыг нь зажилж, аманд нь хийж өгсний дараа залгихаар хүлээж байдаг. Ийм хүмүүс бол хамгийн мунхаг, бусдын

зажилчихсан хоолыг идэх дуртай. Энэ ч бас хүний хамгийн залхуу талын илрэл юм. Миний эдгээр үгийг сонсоод чи цаашид тоолгүй өнгөрөх ёсгүй. Чи анхаарлаа улам нэмэгдүүлснээр л зөв юм хийх бөгөөд тэгсэн цагт л Миний хүслийг хангана. Энэ бол хамгийн шилдэг хүлцэнгүй, дуулгавартай байдал билээ.

63-Р БҮЛЭГ

Чи өөрийн нөхцөл байдлыг ойлгож, түүнчлэн алхах хэрэгтэй замынхаа талаар сайн мэдэж байх ёстой; чихийг чинь нээж, чамд аливааг хэлж өгөхийг Надаас хүлээхээ боль. Би хүний зүрх сэтгэлийн гүнийг ажигладаг Бурхан бөгөөд чиний бодол, санаа нэг бүрийг мэддэг. Түүгээр ч зогсохгүй чиний үйлдэл, зан авирыг Би ойлгодог боловч энэ бүхэн Миний амлалтыг агуулдаг уу? Энэ бүгд нь Миний хүслийг агуулдаг уу? Чи ер нь үүнийг үнэхээр эрж хайж үзсэн үү? Чи үнэхээр үүнд цаг зарцуулсан уу? Чи үнэхээр ямар нэгэн хүчин чармайлт гаргасан уу? Би чамайг шүүмжилж байгаа юм биш; та нар зүгээр л энэ талыг нь үл ойшоосон! Та нар үргэлж машид мунгинаж, юуг ч тодорхой харж чаддаггүй. Үүний шалгаан нь юу болохыг чи мэдэх үү? Учир нь та нарын бодол санаа тодорхой бус бөгөөд үзэл чинь хэтэрхий гүн суусан; түүгээр ч барахгүй та нар Миний хүсэлд огт санаа тавьдаггүй. Зарим хүн, “Бид Таны хүсэлд огт санаа тавьдаггүй гэж Та яаж хэлж чадаж байна вэ? Бид байнга Таны хүслийг ойлгох гэж хичээдэг боловч хэзээ ч амжилтад хүрдэггүй, тэгэхээр бид юу хийх ёстой вэ? Биднийг ямар ч хүчин чармайлт гаргадаггүй гэж Та үнэхээр хэлж болно гэж үү?” гэх болно. Чамаас үүнийг асууя: Чи Надад үнэхээр үнэнч гэж хэлж зүрхлэх үү? Мөн өөрийгөө туйлын үнэнчээр Надад өргөн барьдаг гэж хэн хэлж зүрхлэх вэ? Та нарын дундаас нэг нь ч ингэж хэлж чадахгүй гэдгээс Би айдаг, учир нь та нар дор бүрнээ өөрийн гэсэн сонголт, дуртай зүйлтэй, үүнээс ч илүүтэйгээр өөрийн гэсэн санаа зорилготой байдаг гэдгийг Би хэлэх нь илүүц юм. Ов мэхтэй бүү бай! Зүрх сэтгэлийн гүн дэх бодлыг чинь Би аль эрт нэгд нэгэнгүй ойлгосон. Би үүнийг одоо ч гэсэн тодруулах шаардлагатай юу? Чи бүх талаас нь (өөрийн бодол, санаа, ярьдаг юм бүхэн, үг бүр, хийдэг үйл хөдлөл бүрийн чинь цаана байгаа санаа зорилго болон сэдэл) илүү их шинжлэх ёстой; ийм маягаар чи бүх тал руу орох болно. Түүнчлэн, өөрийгөө бүрэн гүйцэд үнэнээр зэвсэглэж чадна.

Би та нарт ийм зүйлсийг хэлээгүй бол та нар Миний хүсэлд санаа тавих ямар ч хүсэлгүй, өдөржингөө махан биеийн таашаалыг хүсэмжлэн мунгинасан хэвээр байх байсан. Би та нарыг аврахын тулд Өөрийн элэгсэг гарыг үргэлж ашиглаж байна. Та нар үүнийг мэдэх үү? Та нар үүнийг ухаарсан уу? Би чамайг чин сэтгэлээсээ хайрладаг. Чи чин сэтгэлээсээ Намайг хайрладаг гэж хэлж зүрхлэх үү? Өөрөөсөө үүнийг байнга асуу: Чи өөрийн бүх үйлдлийг Надад шалгуулахаар Миний өмнө үнэхээр ирж чадах уу? Чи өөрийн бүх үйлдлийг Надаар үнэхээр шинжлүүлж чадах уу? Би чамайг цадиггүй, өөрийгөө өмгөөлөх гэж дайрдаг гэж хэлнэ. Миний шүүлт

чам дээр ирдэг; одоо чи үнэнийг ухаарах ёстой! Миний ярьдаг бүхэн үнэн; Миний үг чиний доторх бодит нөхцөл байдлыг хэлдэг. Аяа, хүн төрөлхтөн! Харьцахад маш хэцүү юм. Бодит нөхцөл байдлыг чинь хэлэх үед л та нар Миний хэлснийг чин сэтгэлээсээ хүлээж авдаг. Хэрвээ Би үүнийг хийгээгүй бол та нар хуучирсан үзэл санаатайгаа үргэлж зууралдаж, сэтгэлгээний хэв маягаасаа салдаггүй, та нараас илүү ухаантай хэн ч газар дэлхий дээр байхгүй хэмээн боддог. Үүн дээр ердөө л өөрийгөө зөвтгөж байгаа хэрэг биш үү? Чи өөртөө сэтгэл ханаж, бардамнаж, биеэ тоосон, ихэрхүү байгаа хэрэг биш үү? Одоо чи үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой! Өөрийгөө ухаантай, гайхамшигтай гэж бодох хэрэггүй; харин ч өөрийн дутагдал, сул талыг байнга мэдэж байх ёстой. Ингэвэл Намайг хайрлах шийдвэр чинь буурахгүй, харин улам илүү хүчтэй болж, нөхцөл байдал чинь улам дээрдэнэ. Илүү чухал нь чиний амь өдөр өдрөөр улам өсөж дэвших болно.

Миний хүслийг ойлгож авах үедээ чи өөрийгөө мэдэж авч, тэгснээрээ Миний талаар илүү сайн ойлголттой болж, Миний талаарх итгэл чинь улам өсөх болно. Одоо хэрэв хэн нэгэн Надад ерэн хувь итгэлтэй байж чадахгүй, харин нэг хоромд сэтгэл хөөрч, дараагийн хоромд сэтгэлээр унаж, санаагаа байнга өөрчилдөг бол тэр хүн гарцаагүй хөсөр хаягдах нэгэн гэж Би хэлнэ. Үлдсэн арван хувь нь бүхэлдээ Миний гэрээрэл, гэрэлтүүлэлтээс хамаардаг; тийнхүү хүмүүс Надад зуун хувь итгэлтэй болж чадна. Яг одоо буюу өнөөдөр хэчнээн хүн ийм биеийн хэмжээнд хүрч чадах вэ? Би чамд Өөрийн хүслийг байнга илчилж байгаа бөгөөд чиний дотор амийн мэдрэмж зогсолтгүй гүйдэг. Гэтэл чи яагаад Сүнсэнд нийцүүлж үйлддэггүй юм бэ? Чи алдаа гаргахаас айж байна уу? Хэрэв тийм бол яагаад чи сургалтыг огт анхаардаггүй юм бэ? Хүмүүс зүгээр нэг ганц хоёр удаа оролдоод Миний хүслийг ухаарч чадахгүй гэдгийг Би чамд хэлье; тэд процесс туулах ёстой. Би үүнийг олон удаа хэлж байсан, гэтэл чи яагаад үүнийг хэрэгжүүлдэггүй юм бэ? Чи өөрийгөө дуулгаваргүй байгаа гэж бодохгүй байна уу? Чи хүчин чармайлт гаргаж, аливаад цаг хугацаа зарцуулахыг огт хүсэхгүйгээр бүх зүйлийг агшин зуур дуусгахыг хүсдэг. Чи ямар мунхаг, түүнчлэн ямар мэдлэггүй юм бэ!

Би Өөрийн үгийг зөөлрүүлэхгүйгээр аливаа зүйлийн талаар байнга ярьж байдгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нар яагаад ухвар мөчид, хөшүүн, мулгуу байсаар байгаа юм бэ? Та нар өөрсдийгөө илүү их шинжилж, ямар нэг ойлгохгүй зүйл байвал Миний өмнө илүү их ирэх ёстой. Би чамд үүнийг хэлье: Миний ингэж тэгж ярьж байгаа нь Өөрийнхөө өмнө та нарыг хөтөлж авчрах зорилготой юм. Ийм урт хугацааны дараа яагаад та нар одоо хүртэл ухаардаггүй юм бэ? Миний үг та нарыг будилуулсан болохоор уу? Эсвэл та нар Миний нэг ч үгийг нухацтай авч үзээгүйгээс үү? Та нар тэдгээрийг уншаад өөрсдийнхөө талаар сайн мэдлэгтэй болж, үргэлжлүүлэн Надад өртэй, Миний хүслийг ухаарч чадахгүй байна гэх мэтийн зүйл хэлдэг. Гэхдээ дараа нь яадаг вэ? Чи эдгээр зүйлтэй ямар ч холбоогүй мэт; зүгээр л Бурханд итгэдэг хүн биш юм шиг байдаг. Чи өөртөө боловсруулж тунгаах цаг өгөхгүйгээр мэдээллийг зүгээр л ховдоглон залгилж байгаа хэрэг бус уу? Миний

үгийг таашаахдаа чи, морин дэл дээр давхихдаа цэцэгсийг зэрвэс гүйлгэн харж байгаатай адил байдаг; Миний үгээс Миний хүсэл юу болохыг үнэндээ ойлгох гэж хэзээ ч оролддоггүй. Хүмүүс ийм л байдаг: Тэд үргэлж даруу харагдах дуртай байдаг. Ийм хүмүүс хамгийн үзэн ядмаар. Тэд бусадтай нөхөрлөхөөр цугларах үедээ үргэлж бусад хүний өмнө өөрийнхөө талаар мэдлэгийг хуваалцаж, Миний ачаанд санаа тавьдаг нэгэн гэдгээ бусдад харуулах дуртай—үнэн хэрэгтээ тэд бол хамгийн тэнэг мунхгууд юм. (тэд Миний тухай жинхэнэ ойлголт, мэдлэгээ ах эгч нартайгаа нөхөрлөдөггүй; харин ердөө л өөрсдийгөө харуулж, бусдын өмнө гайхуулдаг; тэд Намайг гутааж, дорд үзэж байгаа тул Би ийм хүмүүсийг хамгийн их жигшдэг.)

Би Өөрийн хамгийн агуу гайхамшгийг байнга та нарт илрүүлдэг. Та нар тэдгээрийг харж чадахгүй байна уу? “Бодит байдал” гээчийг Намайг чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүс амьдран харуулдаг. Та нар үүнийг хараагүй гэж үү? Энэ бол та нар Намайг мэдэж чадах хамгийн сайн нотолгоо биш гэж үү? Энэ нь Намайг илүү дээр гэрчилдэггүй гэж үү? Гэвч та нар үүнийг хүлээн зөвшөөрдөггүй. Надад хэлээч: Сатаны завхруулсан, маш бохир, бузар энэ садар самуун дэлхий дээр хэн бодит байдлыг амьдран харуулж чадах вэ? Хүмүүс бүгд завхарсан, хоосон биш гэж үү? Ямартай ч Миний үг дээд цэгтээ хүрсэн; эдгээрээс илүү амархан ойлгож болохуйц үг гэж үгүй. Адгийн тэнэг ч Миний үгийг уншаад, ойлгож чадна—тэгэхээр та нар л хангалттай хүчин чармайлт гаргаагүй юм биш үү?

64-Р БҮЛЭГ

Чи Миний үгийг гажууд, утгагүй байдлаар ойлгох ёсгүй; тэдгээрийг бүх талаас нь ойлгох учиртай бөгөөд илүү сайн ойлгохоор хичээж, ганцхан өдөр, ганцхан шөнө бус, ахин дахин тунгаах хэрэгтэй. Миний хүсэл хаана оршдог, эсвэл ямар талд Би уйгагүй төлөөс төлснийг чи мэддэггүй; чи яаж Миний хүсэлд анхаарал хандуулж чадах билээ? Хүмүүс та нар ийм л байдаг—юмыг нарийвчлан үзэж огт чаддаггүй, зөвхөн гадна талд төвлөрч, дуурайж л чаддаг. Үүнийг яаж сүнслэг байдал гэж хэлэх юм бэ? Энэ бол ердөө хүний урам зориг; мөн Миний сайшаадаггүй зүйл, түүнчлэн Миний жигшдэг зүйл билээ. Би чамд хэлье: Миний жигшдэг бүх зүйл таягдан хаягдаж, гамшигт зовж зүдэрч, Миний шатаалт болон шүүлтийг туулах ёстой. Эс бөгөөс хүмүүс айдас гэж юу болохыг мэдэхгүй бөгөөд ихэд замаа алдаж, Намайг үргэлж хүний нүдээр харах болно—тэд маш мунхаг! Надтай ойртож, Надтай ярилцах нь Сатаны үзэл бодлыг арилгах хамгийн шилдэг арга юм. Та бүхэн шүүгдэж, аминдаа хохирол амсахаас зайлсхийхийн тулд энэ дүрмийн дагуу үйлдээсэй гэж Би хүсэж байна.

Хүмүүс бол харьцахад маш хэцүү, үргэлж л гаднын хүмүүс, үйл явдал, юмсын хяналтад, мөн өөрсдийн үзлийн хяналтад байдаг. Үүний үр дүнд тэд Миний төлөө

сайн гэрчлэл хийж чаддаггүй, Надтай сайтар хамтран ажиллаж чаддаггүй. Би байнга та нарыг дэмжиж, асардаг атал та нар Надтай хамтран ажиллахын тулд хамаг чадлаараа хийх чадваргүй байдаг. Энэ бүхэн Намайг ойлгох ойлголт чинь дутмаг байгааг хангалттай харуулдаг. Чи Миний талаар огт эргэлзэхээ болих цаг ирэхэд үнэн замаар алхахад чинь хэн ч саад болж чадахгүй бөгөөд хүний ямар ч үзэл чамайг ноёрхож чадахгүй. Би яагаад ингэж хэлдэг вэ? Чи Миний айлдварын утга учрыг үнэхээр ойлгодог уу? Иймэрхүү үгийг тодруулах үед минь л та нар багахан ойлголттой болдог. Хүмүүс маш тэнэг, үнэхээр усан толгойтой. Яс маханд нь зүү хүрэх үед л бага зэргийн өвдөлт мэдэрч эхэлдэг. Өөрөөр хэлбэл, Миний үг өвчний эх үүсвэрийг чинь хэлж өгөх үед л чи бүрэн үнэмшдэг. Гэсэн ч заримдаа та нар Миний үгийг хэрэгжүүлж, өөрсдийгөө мэдэхийг мөн л хүсдэггүй. Одоо ч гэсэн та нар хүмүүстэй харьцах хэчнээн хэцүү болохыг яагаад ойлгоогүй хэвээр байна вэ? Миний үг хангалттай илэрхий, тодорхой биш болохоор уу? Та нар Надтай чин, үнэн сэтгэлээсээ хамтран ажиллаасай гэж Би хүсдэг; таатай сонсогдох үг хэлдэг эсэх чинь хамаагүй, Надтай хамтран ажиллах хүсэлтэй байж, Надад үнэн сэтгэлээсээ шүтэн мөргөж чадаж л байвал чи Миний хамгаалалтад орно. Ийм хүн маш мунхаг байсан ч гэсэн Би гэгээрүүлнэ, ингэснээр тэр мунхаг байдлаа хаяж болох юм. Яагаад гэвэл, Миний үйлдэл Миний үгтэй заавал нийцэх ёстой; Би бол биелүүлж чадахгүй амлалт хэзээ ч өгдөггүй Төгс Хүчит Бурхан билээ.

Би Өөрийн хүслийг чуулганууд болон бүх ууган хөвгүүнд шууд илчилнэ, юу ч, хэзээ ч дахин нуугдмал байхаа болино, учир нь бүх зүйл илчлэгддэг өдөр ирчихсэн. Өөрөөр хэлбэл, “нуугдмал” гэдэг үг одоогоос ашиглагдахгүй, тэр ч бүү хэл ямар ч нуугдмал зүйл оршихгүй. Бүх нуугдмал хүн, үйл явдал, зүйл нэг нэгээрээ ил болох нь гарцаагүй. Би бол бүрэн эрх мэдэл эзэмшдэг ухаалаг Бурхан. Бүх үйл явдал, бүх зүйл, хүн нэг бүр Миний гарт байдаг. Тэднийг ил болгохын тулд Би Өөрийн алхмыг хийж, тэднийг нэг нэгээр нь, дэс дараатайгаар дэлгэнэ. Намайг аргалж зүрхэлдэг, эсвэл Надаас ямар нэг зүйл нуухаар оролддог хэнийг ч Би лавтайяа дахин хэзээ ч босгохгүй. Би ийм маягаар үйлдэнэ, ингэснээр та нар бүгдээрээ үүнийг харж чадна. Тодорхой хар! Миний уйгагүй төлсөн төлөөс хий дэмий байгаагүй; энэ нь үр жимсээ өгнө. Анхааралгүй, эсвэл дуулгавартай байгаагүй хэн боловч нэн даруй Миний шүүлттэй тулгарна. Хэн Миний эсрэг явж зүрхлэх юм бэ? Та нар бүгд Намайг дуулгавартай дагах ёстой. Би чамд хэлье: Миний хэлдэг, хийдэг бүхэн, Миний одоогийн үйлдэл, үзэл санаа, бодол, төлөвлөгөө болгон бүгд туйлын зөв; хүн тэдгээрийг цааш нь бодолцон үзэх хэрэггүй. Та нарт зүгээр л дагах хэрэгтэй, энэ талаар цаашид бодож үзэх шаардлагагүй гэж Би яагаад ахин дахин хэлдэг вэ? Шалтгаан нь энэ юм. Би дахиад цааш нь тодруулах хэрэгтэй юү?

Үзэл чинь та нарыг ноёрхдог атал та нар, хангалттай хичээл зүтгэл гаргаагүй учраас ийм байгаа гэдгээ боддоггүй. Үүний оронд шалтаг хайн Над руу харж, Би та нарыг гэгээрүүлээгүй гэж хэлдэг. Энэ ямар гээчийн үг вэ? Чи өөрөө ямар ч хариуцлага хүлээдэггүй, үргэлж Надад гомдоллож байна. Би чамд анхааруулж

байна! Хэрвээ чи ийм маягаар, ямар ч төлөөс төлөлгүйгээр үргэлжлүүлбэл хаягдах болно! Би та нарыг сүрдүүлэх гэж бүхэл өдөржингөө онгирдоггүй. Энэ үнэхээр бодит баримт: Би хэлснээ хийдэг. Миний амнаас гарсан үг тэр даруйдаа шууд хэрэгжиж эхэлдэг. Урьд нь Миний айлдсан үг удаан хэрэгждэг байсан; гэтэл одоо бол юмс өөр бөгөөд цаашид аливаа зүйл удаан тохиолдохгүй. Илүү тодорхой хэлэх юм бол, Би та нарыг цаашид түлхэж, ятгахгүй; харин оронд нь та нарыг зоригжуулж, хүчилдэг. Бүр тодорхой хэлбэл, хөл нийлүүлж чадаж байгаа хүмүүс ийнхүү хийнэ, харин хөл нийлүүлж чаддаггүй, урагш үргэлжлүүлж чаддаггүй хүмүүс таягдан хаягдана. Би та нартай боломжит бүхий л аргаар, тэвчээртэйгээр ярьдаг байсан боловч та нар ердөө сонсоогүй. Одоо ажил энэ үе шат хүртлээ үргэлжилсэн болохоор та нар юу хийх вэ? Та нар үнэхээр өөрсдийгөө өөгшүүлсээр л байх уу? Ийм хүмүүс бүрэн төгс болгуулж чадахгүй, харин Надад таягдан хаягдах нь гарцаагүй!

65-Р БҮЛЭГ

Миний үг үргэлж та нарын эмзэг талыг онодог, өөрөөр хэлбэл, та нарын гайтай сул талыг зааж өгдөг; эс тэгвээс та нар яг одоо ямар цаг болсныг огт мэдэхгүй бас л хөдөлж ядсаар байх байсан. Үүнийг мэдэж ав! Би та нарыг аврахын тулд хайрын зам ашигладаг. Та нар яаж байдаг нь хамаагүй, Би Өөрийн сайшаасан зүйлсийг ямар ч алдаагүйгээр гарцаагүй гүйцэлдүүлнэ. Зөвт Төгс Хүчит Бурхан Би алдаа гаргаж болно гэж үү? Энэ хүний үзэл биш гэж үү? Надад хэлээч: Миний хийдэг, хэлдэг бүхэн та нарын төлөө биш гэж үү? Зарим хүн даруухнаар: “Өө, Бурхан минь! Таны хийдэг бүхэн бидний төлөө байдаг, гэтэл бид Тантай хэрхэн гар нийлэн ажиллахаа мэддэггүй” гэж хэлдэг. Ийм мэдлэггүй! Надтай хэрхэн хамтран ажиллахаа мэдэхгүй гэж хэлэхдээ хүрч байдаг! Эд бүгд ичгүүртэй худал үгс! Та нар ийм зүйл хэлж байж бодит амьдрал дээр яагаад махан биеийг ахин дахин анхаардаг юм бэ? Хэлдэг үг чинь сайхан сонсогддог ч та нар амар, таатай байдлаар үйлддэггүй. Та нар үүнийг ойлгох ёстой: Өнөөдөр Би та нараас их юм шаардаагүй, мөн Миний шаардлага та нарын ухаанаас давсан зүйл ч биш; харин хүний хийж болмоор зүйлс. Би та нарыг огтхон ч хэтрүүлэн үнэлдэггүй; Би хүний чадлын хэмжээг мэдэхгүй гэж үү? Би энэ талаар тов тодорхой ойлголттой.

Миний үг та нарыг байнга гэгээрүүлдэг атал зүрх сэтгэл чинь дэндүү хатуурсан ба сүнсэн дотроо Миний хүслийг ухаарч чаддаггүй! Надад хэлээч: Хоол унд, хувцас хунар болон гадаад төрхдөө анхаарал хандуулахын оронд дотоод аминд анхаарлаа хандуул гэж Би хэчнээн олон удаа сануулсан билээ? Гэтэл та нар ердөө сонсдоггүй. Би хэлж ярихаас залхаж байна. Та нар ийм хөшүүн болчихсон юм уу? Та нар үнэхээр мэдрэмжгүй юм уу? Миний хэлсэн үг хий дэмий өнгөрсөн юм гэж үү? Би ямар нэгэн буруу юм хэлчихээ юү? Миний хөвгүүд ээ! Миний чин сэтгэлийн

санаа зорилгод хайхрамжтай бай! Та нарын амь нэгэнт төлөвшихөд санаа зовох хэрэггүй болох бөгөөд бүх зүйл хангагдана. Эдгээр зүйлд яг одоо анхаарал тавих нь ямар ч үнэ цэнэгүй. Миний хаанчлал бүхэлдээ биеллээ олж, дэлхийд ил тод бууж ирсэн; энэ нь Миний шүүлт бүхэлдээ ирчихсэн гэдгийг бүр илүү илтгэдэг. Та нар үүнийг туулсан уу? Би та нарыг шүүх дургүй боловч та нар Миний зүрх сэтгэлийг огтхон ч хайхардаггүй. Та нар өршөөлгүй шүүлт биш, харин Миний хайр, хамгаалалтыг үргэлж хүртээсэй гэж Би хүсдэг. Та нар шүүгдэхийг хүсдэг байж болно гэж үү? Үгүй бол яагаад та нар байн байн Над руу ойртож, Надтай нөхөрлөж, харилцаатай байдаггүй юм бэ? Та нар Надад маш хөндий хүйтэн ханддаг атлаа Сатан та нарт санаа өгөхөд баярлаж, хүсэлтэй чинь санаа нийлж байна хэмээн боддог—гэтэл чиний хийдэг юу ч Миний төлөө байдаггүй. Та нар Надад үргэлж ийм харгис хэрцгий хандахыг хүсдэг юм уу?

Би чамд өгөхийг хүсдэггүй юм биш, харин та нар төлөөс төлөхийг хүсдэггүй. Иймээс чи юу ч бариагүй, гар хоосон байдаг. Ариун Сүнсний ажил хэчнээн хурдан ахиж байгааг харахгүй байна уу? Миний зүрх сэтгэл тэсэн ядан шатаж байгааг харахгүй байна уу? Би та нараас Надтай хамтран ажиллахыг шаарддаг ч та нар хүсэхгүй хэвээр байдаг. Янз бүрийн гай гамшиг ар араасаа тохиолдоно; бүх улс үндэстэн, бүх газар нутагт гай зовлон тохионо: хаа сайгүй тахал, өлсгөлөн, үер, ган гачиг гарч, газар хөдөлж байна. Эдгээр гай гамшиг ганц хоёрхон газар тохиолдоод, ганц хоёрхон өдөрт ч дуусахгүй; харин ч улам, улам өргөн хүрээг хамран тэлж, гай гамшгууд улам бүр ноцтой болно. Энэ үед элдэв төрлийн шавжны тахал ээлж дараалан дэгдэж, хүн бие биеэ барьж идэх үзэгдэл хаа сайгүй тохиолдоно. Энэ бол бүх үндэстэн, хүмүүст өгч байгаа Миний шүүлт юм. Миний хөвгүүд ээ! Та нар зовлон шаналал, гай гамшгийн хүнд хэцүүд нэрвэгдэх ёсгүй. Та нар удалгүй насанд хүрч, Миний мөрөн дээрх ачааг аль болох хурдан аваасай гэж Би хүсдэг. Миний хүслийг яагаад ойлгодоггүй юм бэ? Урдах ажил улам л амаргүй болно. Та нар Намайг бөөн ажилтай нь ганцаараа махран зүтгэг гээд үлдээх тийм хатуу зүрх сэтгэлтэй юм уу? Би арай энгийнээр хэлье: Амь нь төлөвшсөн хүмүүс хоргодох газарт орох ба зовлон шаналал, хатуу хэцүүд нэрвэгдэхгүй; амь нь төлөвшөөгүй хүмүүс зовлон шаналал, хор хохирол амсах ёстой. Миний үг хангалттай тодорхой биш байна гэж үү?

Миний нэр бүх зүгт, бүх газар түгэх ёстой, тийнхүү хүн бүр Миний ариун нэрийг мэдэж, Намайг мэдэж болох юм. АНУ, Япон, Канад, Сингапур, Зөвлөлт Холбоот Улс, Макао, Хонг Конг болон бусад улсын нийгмийн бүх давхаргын хүмүүс Хятадад нэн даруй цугларч, үнэн замыг хайна. Миний нэр тэдэнд хэдийнээ гэрчлэгдсэн; тэднийг хариулж, удирдахын тулд та нар аль болох хурдан төлөвших л үлджээ. Ийм учраас, улам ч их ажил бий гэж Би хэлдэг. Гай гамшгийн үр дүнд Миний нэр өргөнөөр түгэх бөгөөд хэрвээ та нар болгоомжтой байхгүй бол хүртэх ёстой хувиа алдана. Айхгүй байна уу? Миний нэр бүх шашин, нийгмийн бүх давхарга, бүх үндэстэн, бүх урсгалд түгдэг. Энэ бол Миний ажил уялдаа холбоотойгоор, цэгцтэй

хийгдэж байгаа хэрэг юм; энэ бүгд Миний ухаалаг зохицуулалтаар тохиолддог. Та нар алхам бүрдээ урагшилж, Миний мөрийг ойрхон дагаж чаддаг байгаасай гэж л Би хүснэ.

66-Р БҮЛЭГ

Миний ажил энэ үе шат хүртэл үргэлжилж, бүгд Миний гарын ухаалаг зохицуулалтуудыг дагасан, энэ бүхэн Миний асар их амжилт байсаар ирсэн. Хүмүүсийн дундаас хэн ийм зүйл хийж чадах билээ? Харин ч хүмүүс Миний удирдлагад саад болдоггүй гэж үү? Гэхдээ хэн ч Миний оронд Миний ажлыг хийж чадахгүй, саад болж бүр ч чадахгүй, учир нь Миний хэлж, хийдэг зүйлсийг хэлж, хийж чадах хэн ч байхгүй гэдгийг чи мэдэх ёстой. Хэдий тийм ч, хүмүүс ухаалаг Төгс Хүчит Бурхан Намайг мөн л мэддэггүй! Чи гаднаа Намайг ил тод эсэргүүцэж зүрхэлдэггүй ч зүрх сэтгэл, оюун санаандаа өөрийгөө Миний эсрэг тавьдаг. Тэнэгүүд! Намайг хүний дотоод зүрх сэтгэлийг хардаг Бурхан гэдгийг мэддэггүй юм уу? Би үг, үйлдэл бүрийг чинь хардгийг мэддэггүй юм уу? Би чамд хэлье: Би амаараа дахин хэзээ ч зөөлөн үг айлдахгүй. Харин Миний үг бүгд хатуу шүүлтийн үг байх бөгөөд тэдгээрийг тэсэж дааж чадах эсэхийг чинь Би харна. Одоогоос эхлэн, зүрх сэтгэл нь Надад ойр биш хүмүүс буюу Намайг чин сэтгэлээсээ хайрладаггүй хүмүүс бол Намайг илт эсэргүүцдэг хүмүүс юм.

Өнөөдөр, Ариун Сүнсний ажлын урьдын арга барил хэрэглэгдэхээ болих цэгт хүрсэн; харин оронд нь шинэ арга барил хэрэгжиж байна. Надтай эергээр, идэвхтэйгээр хамтран ажилладаггүй хүмүүс Үхэгсдийн орон буюу үхлийн хөндий рүү унана (энэ хүмүүс үүрд мөхөх болно). Шинэ арга барил дараах байдалтай байдаг: Хэрвээ зүрх сэтгэл, оюун санаа чинь зөв биш бол Миний шүүлт чам дээр даруйхан ирнэ. Үүнд дэлхий ертөнц, эд баялаг, гэр бүл, нөхөр, эхнэр, хүүхдүүд, эцэг эх, хоол, унд, хувцас хунар болон сүнсний ертөнцийн нэг хэсэг бус ийм бүх зүйлтэй зууралдах явдал багтдаг. Ариун хүмүүсийн гэгээрэл улам бүр ил болно; өөрөөр хэлбэл, амийн мэдрэмжүүд улам бүр илэрхий болж, байнга хөдөлгөөнд байна. Өчүүхэн төдий саад тотгор үүсгэсэн хэн боловч гамшигт унаж, амийн уралдааны зам дээр хол хоцорно. Хайхрамжгүй, сүсэг бишрэлтэйгээр эрж хайдаггүй хүмүүсийг Би бүрмөсөн орхиж, нэгийг нь ч үлдээлгүйгээр бүгдийг нь үл ойшооно. Тэд мянган жилийн турш гамшигт зовж зүдэрнэ. Гал цогтойгоор эрж хайдаг хүмүүс буюу үргэлж саад болж буй хүмүүсийг Би мэдлэггүй байдлаас нь ангижруулж, тэднийг Өөртөө үнэнч болгоно. Түүнчлэн тэд мэргэн ухаан, оюун ухаантай болж, улмаар бүр ч их итгэлтэйгээр эрж хайна. Өөрийн ууган хөвгүүдэд өгөх ерөөлүүдээ Би хоёр дахин ихэсгэж, Миний хайр цаг үргэлжид та нарт ирнэ. Би цаг ямагт та нарыг харж хандаж, хамгаалдаг бөгөөд та нарыг Сатаны торонд унагахгүй. Би Өөрийн ажлыг бүх хүний дунд явуулж эхэлсэн; өөрөөр хэлбэл, Би өөр

нэг ажлын төслийг нэмсэн. Энэ бол мянган жилийн турш Христэд үйлчлэл үзүүлэх хүмүүс бөгөөд асар олон тооны хүмүүс Миний хаанчлал руу шавна.

Миний хөвгүүд ээ, та нар сургалтаа эрчимжүүлэх ёстой. Хүлээн аваад, хийж дуусгах ёстой ихээхэн ажил та нарыг хүлээж байгаа. Та нар хурдан төлөвшиж, Миний даалгасан ажлыг дуусгаасай гэж л Би хүсдэг. Энэ бол та нарын ариун хариуцлага, Миний ууган хөвгүүд та нарын гүйцэтгэх ёстой үүрэг билээ. Би та нарыг замын төгсгөл хүртэл хамгаалж, Надтай хамт үүрд аз жаргал эдлээсэй гэсэндээ та нарыг хамгаална. Та нарыг төгс болгохын тулд Би олон золиос гаргаж, олон орчныг зохицуулсан гэдэг баримтыг та нар дор бүрнээ мэдэж авах ёстой. Эдгээр нь бүгд Миний ерөөл гэдгийг та нар мэднэ биз дээ? Та нар бол бүгд Миний хайртай хөвгүүд. Намайг чин сэтгэлээсээ хайрласаар байгаа цагт Би та нарын нэгийг ч хаяхгүй—гэхдээ энэ нь Надтай эв зохицолтойгоор хамтран ажиллах чадвартай эсэхээс чинь хамаардаг.

67-Р БҮЛЭГ

Миний хөвгүүд ил тодоор, бүх хүний өмнө гарч ирдэг. Тэднийг илт эсэргүүцэж зүрхэлдэг хүмүүсийг Би хатуу чанга гэсгээнэ; энэ бол гарцаагүй. Өнөөдөр, өндийн босож, чуулганыг хариулах чадвартай бүх хүн ууган хөвгүүдийн байр суурийг олж авсан бөгөөд одоо Надтай хамт алдар суут байдалд байна—Миний бүх зүйл бас та нарынх. Надад чин сэтгэлээсээ захирагддаг бүх хүнд Би элбэг нигүүлсэл хайрладаг болохоор чи бусад хүний хүч чадлаас давсан хүчтэй болж болох юм. Миний хүсэл бүхэлдээ ууган хөвгүүд та нарт байдаг бөгөөд та нар аль болох хурдан төлөвшиж, Миний даалгасан зүйлийг гүйцэлдүүлээсэй гэж л Би хүсдэг. Үүнийг мэдэж ав! Та нарт Миний даалгасан зүйл бол Миний удирдлагын төлөвлөгөөний эцсийн төсөл юм. Та нар Надад бүхий л оршихуйгаа бүх зүрх сэтгэл, оюун санаа, хүч чадлынхаа хамт өргөж, Миний төлөө үүнийгээ бүрэн зарлагадаж чаддаг байна л гэж Би найддаг. Цаг хугацаа үнэхээр ямар ч хүнийг хүлээдэггүй, хэн ч, юу ч, ямар ч зүйл Миний ажилд саад болж чадахгүй. Үүнийг мэдэж ав! Миний ажил алхам бүрдээ саадгүй, төвөггүй урагшилдаг.

Би орчлонгоор хөндлөн гулд, газар дэлхийн зах хязгаар хүртэл алхдаг, Миний нүд хүн нэг бүрийг байнга шинжилдэг, түүнчлэн Би орчлон ертөнцийг бүхэлд нь хардаг. Миний үг үнэндээ орчлон ертөнцийн булан тохой бүрд ажилладаг. Миний төлөө үйлчлэл хийхгүй зүрхэлдэг, Надад үнэнч бус байж, Миний нэрийг шүүж, Миний хөвгүүдийг доромжилж, гүжирдэж зүрхэлдэг хэн ч бай—үнэхээр ийнхүү үйлддэг бүх хүн хатуу шүүлт амсах ёстой. Миний шүүлт бүхэлдээ бууж ирэх ба өөрөөр хэлбэл, одоо үе бол шүүлтийн эрин, анхааралтай ажиглавал Миний шүүлт орчлон ертөнц даяар тархсаныг та нар олж мэднэ. Мэдээж, Миний гэр ч үүнээс ангид биш; бодол, үг, үйлдэл нь Миний хүсэлтэй нийцдэггүй хүмүүс шүүгдэнэ. Миний шүүлт ганцхан бүлэг хүмүүс юм уу, хэсэг зүйл рүү биш, бүхий л орчлон

ертөнц рүү чиглэдэг гэдгийг та нар ойлгох ёстой. Та нар үүнийг ухаарч авсан уу? Хэрвээ сэтгэлийн чинь гүнд Надтай зөрчилдсөн бодол байх аваас чи тэр даруй дотуураа шүүгдэнэ.

Миний шүүлт бүхий л дүрс, хэлбэрээр ирдэг. Үүнийг мэдэж ав! Би бол орчлон ертөнцийн цор ганц, ухаалаг Бурхан! Юу ч Миний хүч үл хүрэх юм үгүй. Миний шүүлт бүгд та нарт илчлэгдсэн: Хэрвээ чи бодол санаандаа Надтай зөрчилддөг бол Би анхааруулга өгч, чамайг гэгээрүүлнэ. Хэрвээ чи сонсохгүй бол Би чамайг нэн даруй орхино (энд Би Миний нэрд эргэлзэх тухай биш, харин бие махбодын таашаалд холбоотой гаргадаг ааш авирыг хэлж байна). Хэрвээ чиний бодол Намайг эсэргүүцдэг, чи Надад гомдоллодог, мөн Сатаны үзэл санааг ахин дахин хүлээн зөвшөөрч, амийн мэдрэмжүүдийг дагадаггүй бол сүнс чинь харанхуйд байх бөгөөд махан бие чинь зовж шанална. Чи Надад илүү ойр байх ёстой. Өөрийнхөө хэвийн нөхцөл байдлыг ганц, хоёрхон өдрийн дотор сэргээж яавч чадахгүй бөгөөд амь чинь илт хол хоцорно. Үг яриа нь замбараагүй хүмүүсийн ам, хэлийг Би сахилгажуулж, хэлний чинь учрыг олно. Үйл хэрэг нь цадигаа алдсан замбараагүй хүмүүст Би сүнсээр нь сэрэмжлүүлж, сонсдоггүй хүмүүсийг хатуу гэсгээнэ. Намайг ил тод шүүж, эсэргүүцдэг буюу үг хэл, үйл хэргээрээ дуулгаваргүйгээ харуулдаг хүмүүсийг Би бүрмөсөн таягдан хаяж, орхиж, мөхөөж, дээд зэргийн ерөөлүүдийг алдахад хүргэнэ; тэд бол сонгогдсоныхоо дараа таягдан хаягдах хүмүүс юм. Мэдлэггүй буюу үзэгдэл нь тодорхой бус хүмүүсийг Би мөн л гэгээрүүлж, аварна; гэхдээ үнэнийг ойлгодог атлаа хэрэгжүүлдэггүй хүмүүсийг мунхаг ч бай, үгүй ч бай, дээр дурдсан дүрмүүдийн дагуу шийтгэнэ. Анхнаасаа санаа зорилго нь буруу байсан хүмүүсийн хувьд Би бодит байдлыг хэзээ ч ухаарахааргүй болгох бөгөөд эцэст нь тэд нэг нэгээрээ аажмаар таягдан хаягдана. Тэд Миний зохицуулалтаар одоо байгаа боловч нэг нь ч үлдэхгүй (Би аливааг хуумгай хийдэггүй, харин дэс дараалалтай хийдэг).

Миний шүүлт бүрэн илчлэгдсэн; энэ нь бүгд зохих байр сууриа эзлэх ёстой янз бүрийн хүмүүс рүү чиглэдэг. Аль дүрмийг зөрчсөнөөс шалтгаалан Би тухайн дүрмийн дагуу тэднийг шийтгэж, шүүнэ. Энэ нэрд байхгүй, эцсийн өдрүүдийн Христийг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсийн тухайд бол ганцхан л дүрэм бий: Намайг эсэргүүцдэг хэний ч сүнс, сэтгэл, биеийг Би даруйхан авч, Үхэгсдийн орон руу хаяна; Намайг эсэргүүцдэггүй хэний ч тухайд бол, Би хоёр дахь шүүлт явуулахаасаа өмнө төлөвшихийг нь хүлээнэ. Миний үг бүхнийг тов тодорхой тайлбарладаг бөгөөд юу ч нуудаггүй. Та нар тэдгээрийг оюун санаандаа цаг ямагт тээж чаддаг байна гэж л Би найдна!

68-Р БҮЛЭГ

Миний үг улс орон, газар, үндэстэн, урсгал бүрд хэрэгжиж, хэдийд ч өнцөг булан бүрд биелж байна. Хаа сайгүй тохиолддог гай гамшгууд нь хүмүүсийн хоорондох тулаан ч биш, зэвсэг хэрэглэдэг байлдаан ч биш. Дараа нь дайн гарахаа болино.

Бүгд Миний гарт байна. Бүгд Миний шүүлттэй нүүр тулж, гай гамшиг дунд зовж зүдэрнэ. Намайг эсэргүүцдэг, бас Надтай хамтран ажиллах санаачилга гаргадаггүй хүмүүс янз бүрийн гай гамшгийн зовлон шаналлыг амсаг; Тэд үүрд уйлж, шүдээ хавирч, харанхуйд үүрд үлдэг. Тэд амьд үлдэхгүй. Би шулуун шударгаар, хөнгөн шаламгай үйлддэг бөгөөд урьд нь Надад хэчнээн үнэнч байсныг чинь харгалзан үздэггүй; чи Намайг эсэргүүцэж байгаа цагт Миний шүүлтийн гар уур хилэнгээ чам дээр огт цааргалалгүй, ганц секунд ч хүлээлгүй, ямар ч өршөөлгүйгээр үтэр түргэн буулгана. Би хэлсэндээ хүрдэг Бурхан гэдгээ чамд тувт хэлсээр ирсэн. Миний хэлсэн үг бүр биелж, та нарт бүгдийг нь нэг бүрчлэн харуулна. Энэ бол бүх зүйлд бодит байдал руу орно гэдгийн жинхэнэ утга юм.

Миний хайртай Миний хөвгүүдэд их гамшиг мэдээж тохиолдохгүй. Би хөвгүүдээ агшин тутам, секунд бүрд харж хандана. Та нар лав тэрхүү шаналал, зовлонг туулахгүй. Харин ч үүний зорилго бол Миний хөвгүүдийг төгс болгож, Миний үг тэдэнд биелэхийн тулд байдаг. Ингэснээр та нар Миний бүхнийг чадагч байдлыг танин мэдэж, амиа цаашид өсгөж, Миний ачааг удалгүй үүрч, Миний удирдлагын төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн төлөө өөрсдийгөө бүрэн зориулж болох юм. Үүний учир чи бахдал, жаргалтайгаар баярлах хэрэгтэй. Би та нарт бүхнийг гардуулж, хяналтыг гартаа авахыг зөвшөөрнө; хэрвээ хүү нь эцгийнхээ бүхий л өмч хөрөнгийг өвлөж авдаг нь үнэн бол Миний ууган хөвгүүд та нарын хувьд үүнээс илүү үнэн хаана байх вэ? Та нар үнэхээр ерөөгдсөн. Их гамшигт зовохын оронд та нар дуусашгүй ерөөл эдэлнэ. Яасан их алдар суу вэ! Яасан их алдар суу вэ!

Хурдаа нэмж, Миний мөрийг цаг үргэлж, газар сайгүй дага; бүү хоцор. Зүрх сэтгэл чинь Миний зүрх сэтгэлийг дагаг; оюун санаа чинь Миний оюун санааг дагаг. Надтай нэг зүрх сэтгэл, нэг оюун санаагаар хамтран ажилла. Надтай хамт идэж, амьдарч, Надтай хамт эдэл. Та нарыг эдэлж, аваг гээд гайхалтай ерөөлүүд хүлээж байна. Миний дотор үнэхээр харьцуулшгүй элбэг дэлбэг байдал бий. Өчүүхнийг нь ч өөр хэн нэгэнд зориулж бэлтгээгүй; Би үүнийг бүхэлд нь Өөрийн хөвгүүдийн төлөө хийдэг.

Одоо, оюун санаанд минь байгаа зүйл биелнэ. Намайг та нартай ярьж дуусах үед тэдгээр асуудал хэдийн гүйцэлдсэн байх болно. Ажил үнэхээр ийм хурдан үргэлжилж, хором бүрд өөрчлөгдөж байна. Хэрвээ та нарын анхаарал хором ч атугай сатаарах аваас, “төвөөс холдох” үзэгдэл тохиож, та нар маш хол хаягдаж, энэ урсгалыг орхих болно. Хэрвээ та нар чин сэтгэлээр эрж хайдаггүй бол Миний уйгагүй хичээл чармайлтыг хий дэмий болгоно. Хожим янз бүрийн улс үндэстний хүмүүс хэдийд ч хамаагүй чихцэлдэн зүтгэнэ. Одоогийн түвшнээрээ та нар тэднийг удирдаж чадах уу? Өөрийн даалгаврыг гүйцэлдүүлэх үүднээс Би та нарыг энэ богинохон хугацаанд сайн цэргүүд болгохоор нэгд нэггүй сургана. Та нар Миний нэрийг бүх талаар алдаршуулж, Надад гайхалтай гэрчлэл хийгээсэй гэж Би хүсдэг. Тэдний жигшдэг байсан хүмүүс дээр нь зогсож, тэднийг удирдаж, захираг. Миний санаа зорилгыг ойлгож байна уу? Миний уйгагүй хичээл чармайлтыг ухаарав уу?

Би энэ бүхнийг та нарын төлөө л хийдэг. Та нар Миний ерөөлийг эдэлж чадах эсэхээс энэ нь шалтгаалдаг.

Хүний оюун ухаан, зүрх сэтгэлийг хайдаг Бурхан Би газар дэлхийн зах хязгаар луу аялдаг. Хэн Надад үйлчлэхгүй байж зүрхлэх билээ? Бүх улс үндэстний дунд нөхцөл байдал хурцдаж, хорсолтойгоор тэмцэлддэг; гэвч эцэстээ тэд Миний атгаас зугтахгүй. Би тэднийг амархан хэлтрүүлэхгүй нь лавтай. Тэдний үйлдэл, дэлхийн байр суурь, хорвоогийн зугаа цэнгэл дээр нь үндэслэн нэг нэгээр нь шүүнэ. Би хэнийг ч өршөөхгүй. Миний уур хилэн илчлэгдэж эхэлсэн бөгөөд бүгд тэдэн дээр бууна. Тэдэн дээр бүгд нэг нэгээрээ биелнэ, энэ бүхнийг тэд өөрсөд дээрээ авчирна. Намайг мэдэж чадаагүй, урьд нь Намайг жигшдэг байсан хүмүүс одоо Миний шүүлттэй нүүр тулна. Урьд нь Миний хөвгүүдийг хяхаж хавчсан хүмүүсийн тухайд бол, ялангуяа тэднийг хэлсэн, хийсэн зүйлийнх нь дагуу Би гэсгээнэ. Би хүүхдүүдийг ч өршөөхгүй; энэ хүмүүс бүгд Сатаны төрөл. Тэд юу ч хэлээгүй, хийгээгүй байсан ч гэсэн, зүрх сэтгэлийнхээ гүнд Миний хөвгүүдийг үзэн ядах санаа тээдэг л бол Би нэгийг нь ч өршөөхгүй. Өнөөдөр засаглаж, эрх мэдэл барьдаг хүмүүс нь гарцаагүй тэд биш, харин энэ бүлэг хүмүүс бид гэдгийг Бид бүгдэд нь харуулна. Энэ шалтгаанаар, газар нутаг, өнцөг булан, шашин, урсгал болгонд Миний нэрийг алдаршуулж, гэрчилж, бүх орчлон ертөнцийн зах хязгаар хүртэл түгээхийн тулд та нар бүх хүч чадлаа улам их зориулж, өөрсдийгөө Миний төлөө чин сэтгэлээсээ зарцуулах ёстой.

69-Р БҮЛЭГ

Миний хүсэл гарч ирэхэд эсэргүүцэж, шүүж, эргэлзэж зүрхэлдэг хэнийг ч Би тэр даруй цэвэрлэнэ. Өнөөдөр, Миний хүслийн дагуу үйлддэггүй, Миний хүслийг андуурдаг хэн боловч Миний хаанчлалаас таягдуулж, хаягдах ёстой. Миний хаанчлалд өөр хэн ч байхгүй; бүгд Миний хөвгүүд—Миний хайрладаг, Надад санаа тавьдаг хүмүүс. Түүнчлэн тэд бол Миний үгийн дагуу үйлддэг, Миний өмнөөс бүх үндэстэн, бүх хүнийг шүүн эрх мэдлээр засаглаж чадах хүмүүс юм. Түүнчлэн тэд бол гэм зэмгүй агаад цовоо, эгэл агаад нээлттэй, үнэнч агаад ухаалаг бүлэг ууган хөвгүүн юм. Миний хүсэл та нар дээр ханадаг, Миний хийхийг хүсдэг зүйл ямар ч алдаагүй, бүрэн нээлттэй, ил тодоор та нар дээр биелдэг. Буруу санаа, зорилготой хүмүүсийг Би орхиод эхэлчихсэн, тэднийг нэг нэгээр нь унагаана. Би тэднийг амьд үлдэж чадахааргүй болтол нь нэг нэгээр нь устгана—энэ бүхэн нь тэдний сүнс, сэтгэл, биед нь хамаарна.

Миний гарын үйлдэл—ядууг тэтгэж, Намайг хайрладаг хүмүүсийг халамжлан хамгаалж, Миний удирдлагад хөндлөнгөөс оролцдоггүй мэдлэггүй, хичээнгүй хүмүүсийг аварч, Намайг эсэргүүцдэг, Надтай идэвхтэй хамтран ажилладаггүй хүмүүсийг шийтгэх зэрэг энэ бүх зүйл Миний айлдварын дагуу нэг нэгээрээ

батлагдана гэдгийг ойлго. Чи Намайг үнэхээр хайрладаг хүн мөн үү? Чи Миний төлөө өөрийгөө үнэнчээр зарлагаддаг нэгэн мөн үү? Чи Миний үгийг сонсож, түүний дагуу үйлддэг нэгэн мөн үү? Чи Миний эсрэг нэгэн үү, эсвэл Надтай нийцтэй нэгэн үү? Зүрх сэтгэлийнхээ гүнд эдгээрийн талаар чи тодорхой мэдэж байна уу? Миний хэлсэн зүйл бүрд чи хариулж чадах уу? Хариулж чадахгүй байгаа бол чи урам зоригтойгоор эрж хайдаг боловч Миний хүслийг ойлгодоггүй нэгэн юм. Ийм хүмүүс Миний удирдлагад хамгийн амархан саад болж, Миний хүслийг андуурна. Хэрэв тэд хормын төдийд ч гэсэн буруу санаа зорилготой байвал Би тэднийг цэвэрлэж, устгах болно.

Миний дотор ойлгохын аргагүй хязгааргүй нууц бий. Би тэдгээрийг Өөрийн төлөвлөгөөний дагуу нэг нэгээр нь хүмүүст илчилнэ. Өөрөөр хэлбэл, Би тэдгээрийг Өөрийн ууган хөвгүүдэд илчлэх болно. Шүтлэггүй хүмүүс хийгээд Намайг эсэргүүцдэг хүмүүст Би гагцхүү урсгалаараа явахыг зөвшөөрнө; гэвч эцэст нь тэдэнд Би бол сүр жавхлан, шүүлт гэдгийг ойлгуулах ёстой. Өнөөдрийн шүтлэггүй хүмүүс зөвхөн нүднийх нь өмнө болж байгааг л мэддэг боловч Миний хүслийг мэддэггүй. Миний хайрладаг Миний хөвгүүд л Миний хүслийг мэдэж, ойлгодог. Би хөвгүүддээ Өөрийгөө ил тод илчилдэг; Сатаны хувьд Би бол ерөөсөө ч нуугдмал биш, сүр жавхлан, шүүлт билээ. Энэ өдрүүдэд, Миний хүслийг зөвхөн Миний ууган хөвгүүд мэдвэл зохилтой; өөр хэн ч тэнцэхгүй—энэ бүхнийг Би бүтээлээс өмнө урьдчилан зохицуулсан юм. Хэн ерөөгдөж, хэн зовохыг Би аль эртнээс зохих ёсоор зохицуулсан; Би энэ талаар тов тодорхой хэлсэн бөгөөд өнөөдөр энэ нь аль хэдийн бүрэн биелсэн: Ерөөгдсөн хүмүүс ерөөлөө эдэлж эхэлсэн байхад зовох хүмүүс бас гай гамшиг туулаад эхэлчихсэн. Зовохыг хүсдэггүй хүмүүс ч зовох л болно, учир нь энэ бол Миний урьдчилан тогтоосон, Миний захиргааны зарлигийн гар зохицуулсан зүйл юм. Чухамдаа ямар хүн ерөөгдөж, ямар хүн зовдог вэ? Би эдгээрийг аль хэдийн илчилсэн; энэ та нарт нууц биш, харин ч ил тод зүйл юм: Намайг хүлээн зөвшөөрдөг ч санаа зорилго нь буруу хүмүүс; Намайг хүлээн зөвшөөрдөг ч Намайг эрж хайдаггүй хүмүүс; Намайг мэддэг ч Надад захирагддаггүй хүмүүс; Намайг мэхлэхийн тулд хуурч, урван тэрсэлдэг хүмүүс; Миний үгийг уншдаг ч сөрөг байдал цацдаг, өөрсдийгөө мэддэггүй, юу болохоо мэддэггүй, өөрсдийгөө агуу гэж боддог, өөрсдийгөө нас биед хүрсэн гэж боддог (Сатаны жишээ) ийм хүмүүс бүгд зовлон хүртэх хүмүүс юм. Намайг хүлээн зөвшөөрдөг, санаа зорилго нь Миний төлөө байдаг хүмүүс (хэрэв тэд саад учруулах аваас Би тэдний гэм бурууг санахгүй, гэхдээ тэдний санаа зорилго зөв байх ёстой, тэд үргэлж анхаарал болгоомжтой, замбараагүй биш байх ёстой; тэд Намайг сонсож, Надад захирагдах хүсэл үргэлж тээх ёстой); цэвэр ариун хүмүүс; нээлттэй хүмүүс; үнэнч хүмүүс; аливаа хүн, юм, хэрэг явдалд захирагдаагүй хүмүүс; хүүхэд мэт төрхтэй атлаа амь нь төлөвшсөн хүмүүс—энэ хүмүүс бол Миний хайрт, Миний ерөөлийг хүртэх хүмүүс юм. Одоо та нар дор бүрнээ нөхцөл байдлынхаа дагуу зохих байраа эзэлнэ. Түүнчлэн чи ерөөгдөх, эсвэл зовох эсэхээ мэдэх болно; Би үүнийг илэн далангүй хэлэх хэрэг

байхгүй. Ерөөгдсөн хүмүүс баярлан хөөрч, жаргалтай байх ёстой байхад зовлон амсах хүмүүс гутрах хэрэггүй. Аль алийг нь Миний гар зохицуулсан, гэхдээ үүнд Намайг буруутгах хэрэггүй: Чи өөрөө л Надтай идэвхтэй хамтран ажиллаагүйгээс гадна Би бол хүний зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан гэдгийг ойлгож чадаагүй. Үүнийг Би урьдчилан тодорхойлсон бөгөөд чи шалихгүй заль мэхээрээ өөрийгөө хорлосон; үүнд чи өөрөө л буруутай! Үхэгсдийн орон руу унах ёстой болсон чинь ч тэр чамд зохисгүй хандаж байгаа хэрэг биш! Энэ бол чиний төгсгөл; чиний үр дүн!

Ерөөгдсөн ууган хөвгүүд ээ! Даруй өндийн босож, уухайл! Даруй өндийн босож, магтаал өргө! Одоогоос эхлээд гашуун зовлон, шаналал гэж үгүй; бүх зүйл бидний гарт байна. Бодол санаа нь Минийхтэй бүрэн нийцдэг хэн боловч Миний хайрладаг хүн бөгөөд гай гамшгийг туулах хэрэггүй. Зүрх сэтгэлийн чинь хүсэл юу ч байсан Би биелүүлнэ (гэхдээ энэ нь дур зоргоороо байж болохгүй); энэ бол Миний ажил билээ.

70-Р БҮЛЭГ

Миний нууц илчлэгдэж, нээлттэй харагдаж, нуугдмал байхаа болих нь бүхэлдээ Миний нигүүлсэл, өршөөлөөс болдог. Түүнээс гадна Миний үг хүмүүсийн дунд гарч ирж, цаашид далд бус байх нь мөн л Миний нигүүлсэл болон өршөөлөөс болдог. Миний төлөө өөрсдийгөө чин сэтгэлээсээ зарлагаддаг болон Надад өөрсдийгөө зориулдаг бүх хүнийг Би хайрладаг. Надаас төрсөн мөртөө Намайг мэддэггүй, бүр Намайг эсэргүүцдэг хүмүүсийг Би үзэн яддаг. Миний төлөө чин сэтгэлээсээ байдаг хүмүүсийг Би орхихгүй, харин ч тэднийг хоёр дахин их ерөөнө. Ач санадаггүй, Миний сайхан сэтгэлийг гутаадаг хүмүүсийг Би хоёр дахин илүү шийтгэж, амархан тавьж явуулахгүй. Миний хаанчлалд шударга бус байдал, эсвэл хууран мэхлэлт, дэлхийн зүйл буюу үхэгсдийн үнэр байдаггүй. Харин ч бүгд шударга зан, зөвт байдал; бүгд нууж, далдлах зүйлгүй, ариун, нээлттэй байдал; бүгд шинэлэг, бүгд баяр цэнгэл, бүгд босгон байгуулалт юм. Хэн нэгэн үхсэн хүний өмхий үнэрийг ханхлуулсаар байвал яагаад ч Миний хаанчлалд үлдэж чадахгүй, харин Миний төмөр саваанд захирагдах болно. Балар эртний үеэс өнөөдрийг хүртэлх бүх эцэс төгсгөлгүй нууц эцсийн өдрүүдэд Миний олж авдаг бүлэг хүмүүс та нарт бүрэн илчлэгдсэн. Та нарт ерөөгдсөн санагдахгүй байна уу? Түүнчлэн, бүх юм ил тод харагдах өдрүүд нь та нар Миний хаанчлалыг хуваалцах өдрүүд юм.

Үнэхээр хаад шиг хаанчилдаг бүлэг хүмүүс Миний урьдчилсан тогтоолт болон сонголтоос хамаардаг ба үүнд хүний хүсэл огт байдаггүй. Хэрэв хэн нэгэн үүнд оролцох гэж зүрхэлвээс Миний гарын цохилтыг амсах ёстой бөгөөд ийм хүмүүс Миний дүрэлзэх галын бай болно; энэ бол Миний зөвт байдал, сүр жавхлангийн өөр нэг тал юм. Би бүх зүйлийг захирдаг, Би бол бүрэн эрх мэдэлтэй ухаалаг Бурхан, Би хэнд ч өршөөнгүй ханддаггүй, туйлын энэрэлгүй, ямар ч хувийн

мэдрэмжгүй гэдгээ хэлсэн. Би хэн ч байсан (хэдий сайн ярьдаг байлаа ч Би түүнийг зүгээр өнгөрөөхгүй) Өөрийн зөвт байдал, шударга зан, сүр жавхлангаар ханддаг, энэ зууpаа Миний үйл хэргийн гайхамшиг болон Миний үйл хэрэг юу илэрхийлдгийг илүү сайн харах боломжийг хүн бүрд олгодог. Би үйлдсэн янз бүрийн үйлдлийнх нь төлөө муу ёрын сүнснүүдийг нэг нэгээр нь шийтгэж, тэднийг нэг нэгээр нь ёроолгүй нүхэнд хаясан. Цаг хугацаа эхлэхээс өмнө Миний дуусгасан энэ ажил тэднийг ямар ч албан тушаалгүй, ажиллах газаргүй болгож орхисон. Миний сонгосон хүмүүс буюу Миний урьдчилан тогтоож, сонгосон хүмүүсийн нэг нь ч муу ёрын сүнсэнд хэзээ ч эзэмдүүлэхгүй, харин үргэлж ариун байна. Өөрийн урьдчилан тогтоогоогүй, сонгоогүй хүмүүсийг Би Сатанд өгч, тэдэнд цаашид үлдэхийг зөвшөөрдөггүй. Миний захиргааны зарлиг бүх талаараа Миний зөвт байдал, Миний сүр жавхланг агуулдаг. Би Сатаны ажилладаг хэнийг ч зүгээр өнгөрөөхгүй, харин Би Сатаныг үзэн яддаг учир тэднийг биеийнх нь хамтаар Үхэгсдийн орон руу хаяна. Би үүнийг хэзээ ч амархан өршөөхгүй, харин бүрэн дүүрэн устгаж, ажлаа хийх өчүүхэн ч боломж үлдээхгүй. Сатаны тодорхой хэмжээнд ялзруулсан хүмүүс (гамшгийн бай болсон хүмүүс) Миний гарын ухаалаг зохицуулалт дор байдаг. Үүнийг Сатаны хэрцгий зангаас болж тохиолдсон гэж бүү бод, харин Би орчлон ертөнц болон бүх зүйлийг захирч байдаг Төгс Хүчит Бурхан гэдгийг мэдэж ав! Миний хувьд шийдвэрлэж болохгүй асуудал гэж байхгүй, гүйцэлдүүлж болохгүй зүйл, эсвэл хэлж болохгүй үг гэж бүр ч байхгүй. Хүмүүс Миний зөвлөгч мэт авирлах ёсгүй. Миний гарт цохиулж, Үхэгсдийн орон руу хаягдахаас болгоомжил. Би чамд хэлчихье! Өнөөдөр Надтай идэвхтэйгээр хамтран ажилладаг хүмүүс бол хамгийн ухаалаг хүмүүс бөгөөд тэд хохирлоос зайлсхийж, шүүлтийн шаналлаас мултарна. Энэ бүгд бол Миний зохицуулалт, Миний урьдчилан тогтоолт; хайхрамжгүй үг бүү хэл, өөрийгөө ихэд бодож, бодлогогүй үг бүү ярь. Энэ бүхэн Миний урьдчилан тогтоосноос болоогүй гэж үү? Миний зөвлөгч болох та нар ямар ч ичгүүр сонжуургүй! Та нар өөрсдийн биеийн хэмжээг мэддэггүй, ямар өрөвдөлтэй өчүүхэн билээ! Гэвч та нар үүнийг том асуудал биш гэж боддог ба өөрсдийгөө мэддэггүй. Та нар Миний үгийг ахин дахин чихнийхээ хажуугаар өнгөрөөж, Миний уйгагүй хүчин чармайлтыг хий дэмий үрж, энэ нь Миний нигүүлсэл, өршөөлийн илрэл гэдгийг огт ухаардаггүй. Харин өөрийн овсгоо самбааг ахин дахин гайхуулах гэж оролддог. Үүнийг санаж байна уу? Өөрсдийгөө их ухаантай гэж боддог хүмүүс ямар гэсгээлт хүртэх ёстой вэ? Миний үгэнд хайхрамжгүй, итгэлгүй байж, зүрх сэтгэлдээ сийлдэггүй, энэ тэрийг хийхдээ худал дүр үзүүлэхийн тулд Намайг ашигладаг. Мууг үйлдэгчид ээ! Та нар хэзээ Миний зүрх сэтгэлийг бүхэлд нь бодолцох юм бэ? Та нар Миний зүрх сэтгэлийг бодолцдоггүй, тиймээс та нарыг мууг үйлдэгчид гэж нэрлэх нь зохисгүй хандаж буй хэрэг биш. Харин ч та нарт яг таарна!

Өнөөдөр Би та нарт нэгэнтээ нуугдмал байсан зүйлсийг нэг нэгээр нь харуулж байна. Агуу улаан луу ёроолгүй нүхэнд хаягдаж, бүрэн устгагдсан, учир нь түүнийг байлгах ямар ч хэрэггүй; өөрөөр хэлбэл, энэ нь Христэд үйлчлэл үзүүлж чадахгүй.

Үүнээс хойш, улаан зүйлс оршин тогтнохоо болино; тэдгээр нь ор мөргүй арилах ёстой. Би хэлснээ хийдэг; энэ бол Миний ажлын гүйцэтгэл. Хүний үзлээ арилга; Би хэлсэн бүх зүйлээ хийсэн. Сэргэлэн байх гэж хичээдэг хэн ч өөртөө сүйрэл авчирч, зэвүүцэл төрүүлдэг ба амьдрахыг хүсдэггүй. Тиймээс Би сэтгэлийг чинь хангаж, тийм хүмүүсийг огтхон ч байлгахгүй. Үүнээс хойш хүн ам улам бүр сайжирч, харин санаачилгатайгаар Надтай хамтран ажилладаггүй хүмүүс ор мөргүй үгүй болно. Миний хүлээн зөвшөөрсөн хүмүүс бол Миний төгс болгох хүмүүс бөгөөд Би нэгийг нь ч орхихгүй. Миний хэлдэг зүйлд ямар ч зөрчилдөөн үгүй. Надтай идэвхтэй хамтарч ажилладаггүй хүмүүс улам их гэсгээлт амсах ч эцэст нь Би тэднийг гарцаагүй аварна. Харин тэр үед тэдний амийн хэмжээ нэлээд өөр байх болно. Чи тийм хүн болохыг хүсэж байна уу? Бос, Надтай хамтран ажилла! Миний төлөө чин сэтгэлээсээ өөрсдийгөө зарлагаддаг хүмүүст Би мэдээж хэрэг муу хандахгүй. Надад чин сэтгэлээсээ өөрсдийгөө зориулдаг хүмүүст Би Өөрийн бүх ерөөлийг хайрлана. Өөрийгөө бүхэлд нь Надад өргө! Чиний юу идэж, юу өмсөж зүүх болон чиний ирээдүй бүгд Миний гарт байдаг, чиний дундарч, дуусашгүй баяр баяслын төлөө Би бүхнийг зохих ёсоор зохицуулна, учир нь “Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүмүүсийг Би асар ихээр ерөөх нь гарцаагүй” гэж хэлсэн билээ. Надад өөрийгөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүн болгонд бүх ерөөл очно.

71-Р БҮЛЭГ

Би Өөрийгөө бүхэлд нь та нарт харуулсан атал яагаад та нар Миний үгийг бүх зүрх сэтгэл, оюун санаагаараа тунгаан боддоггүй юм бэ? Яагаад та нар Миний үгийг хог шиг үздэг юм бэ? Миний хэлдэг зүйл буруу гэж үү? Миний үг эмзэг газрыг чинь цохичихсон уу? Та нар байнга хойшлуулж, эргэлзэж байна. Яагаад ингэж авирладаг юм бэ? Би тодорхой хэлээгүй гэж үү? Миний үгийг анхааралтай тунгааж, сайтар анхаарал хандуулах ёстой гэж Би маш олон удаа хэлсэн. Та нараас хэн нэг чинь дуулгавартай, хүлцэнгүй хүүхэд мөн үү? Миний үг хий дэмий байсан уу? Ямар ч үр нөлөөгүй байсан уу? Чиний хэр их нь Миний хүсэлтэй нийцэж чадах вэ? Ганцхан хором л чамтай ярихгүй орхивол чи замбараагүй, хяналтгүй болно. Хэрвээ Би хэрхэн үйлдэж, хэрхэн ярихыг тодорхой өгүүлэхгүй л бол чи зүрх сэтгэлийнхээ гүнд огт мэддэггүй юм гэж үү? Би чамд хэлье! Хохирол амсдаг хүн бол дуулгаваргүй, захирагддаггүй, мунхаглан итгэдэг хүн юм! Миний хэлдэг зүйлд анхаарал тавьдаггүй, нарийн ширийнийг ухаарч чаддаггүй хүмүүс Миний санаа зорилгыг ухан ойлгож чадахгүй, Надад үйлчилж ч чадахгүй. Ийм хүмүүс Миний харьцалтыг туулж, Миний шүүлттэй тулгарна. Нарийн ширийнийг ухаарахгүй байх гэдэг нь туйлын увайгүй, мөн дур зоргоороо байгаа хэрэг юм; тиймээс Би ийм хүмүүсийг үзэн яддаг ба тэдэнд зөөлөн хандахгүй. Би тэдэнд ямар ч өршөөл үзүүлэхгүй; харин Өөрийн бүх сүр жавхлан, шүүлтийг л үзүүлнэ. Тэгээд Намайг мэхэлж зүрхэлсээр байгаа эсэхээ хар.

Би бол хүний зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан. Энэ нь хүн бүрд илэрхий байх ёстой; эс тэгвээс тэд хайхрамжгүй байдлаар ажлаа хийж, Надтай хааш яаш харьцсаар л байх болно. Зарим хүн өөрийн мэдэлгүй Надад цохиулдгийн шалтгаан энэ юм. Би хэнд ч шударга бусаар хандахгүй, буруу зүйл хийхгүй, Миний бүх үйлдэл Миний гарын ухаалаг зохицуулалтаар хийгддэг гэж Би хэлсэн.

Намайг үнэхээр хайрладаггүй бүх хүн дээр Миний шүүлт буусан. Яг энэ үед л, Би хэнийг урьдчилан тогтоож, сонгосон, хэнийг таягдан хаях вэ гэдэг нь тодорхой болно. Эдгээр нь бүгд нэг нэгээрээ илчлэгдэнэ, юу ч нуугдмал хэвээр үлдэхгүй. Бүх хүн, үйл явдал, зүйл Миний үгийг биелүүлэхийн тулд зогсдог бас оршдог бөгөөд Миний амнаас гарсан үгийг биелүүлэх гээд завгүй байдаг. Миний гар дангаараа орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаарыг хянадаг. Миний үгийг дуулгавартай дагахгүй байж зүрхэлдэг, эсвэл Миний үйл хэргийг тунхаглахаас татгалздаг хэнийг ч Би цохин, тэр хүнийг Үхэгсдийн орон руу живүүлж, оршин тогтнохыг нь болиулах ёстой. Миний бүх үг тохиромжтой, зохистой, мөн ямар ч хольцгүй байдаг. Ярьж байгаа байдал чинь Минийхтэй төстэй байж чадах уу? Та нар маш нуршуу; утгагүй юм ярьдаг, өөрсдийгөө тодорхой тайлбарладаггүй мөртөө зарим зүйлийг олж авсан, бараг ойлгочихсон гэж бодсоор байдаг. Би чамд хэлье! Хүн өөртөө сэтгэл хангалуун байх тусам Миний стандартаас төдий чинээ холддог. Тэд Миний хүсэлд хайхрамжтай байдаггүй бөгөөд Намайг хуурч, Миний нэрийг хамгийн ноцтойгоор шившиглэдэг! Ичгүүргүй юм! Та нар ямархуу биеийн хэмжээтэйгээ хардаггүй. Ямар мунхаг, мэдлэггүй юм бэ!

Миний үг цаг үргэлж, бүх талаар аливааг зааж үзүүлдэг. Чи үүнийг мэддэггүй хэвээр байж болно гэж үү? Чи бас л ойлгохгүй байна гэж үү? Чи Намайг сэтгэлээр унагаах гээ юү? Сүнсээ сэргээж, зоригоо чангал. Намайг хайрладаг ганц ч хүнд Би муухай ханддаггүй. Би хүний зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг ба бүх хүний зүрх сэтгэлд байгаа бүгдийг мэддэг. Энэ бүх зүйл нэг нэгээрээ илчлэгдэж, бүгд Надаар шинжлүүлнэ. Би Намайг үнэхээр хайрладаг хэнийг ч, хэзээ ч үл тоомсорлохгүй; тэд бүгд ерөөл хүлээн авагчид, хаан болгохын тулд Миний урьдчилан тогтоосон ууган хөвгүүдийн бүлэг юм. Намайг үнэхээр хайрладаггүй хүмүүсийн тухайд бол, тэд өөрсдийнхөө заль мэхний бай бөгөөд золгүй явдал амсана; үүнийг ч бас Би урьдчилан тогтоосон. Бүү санаа зов; Би тэднийг нэг нэгээр нь илчилнэ. Би энэ ажлыг урьдаас сайтар бэлдсэн бөгөөд аль хэдийн хийгээд эхэлчихсэн. Энэ бүхэн нь эмх цэгцтэй байдлаар хийгдэж байгаа; огтхон ч замбараагүй биш. Хэн сонгогдож, хэн таягдан хаягдахыг Би аль хэдийн шийдсэн. Та нарт харуулахын тулд тэднийг нэг нэгээр нь илчилнэ. Энэ хугацаанд та нар Миний гар юу хийж байгааг харна. Миний зөвт байдал, Миний сүр жавхлан хэн нэгний ямар ч халдлага, эсэргүүцлийг зөвшөөрдгүйг, мөн халдсан хэн ч бай хатуу шийтгүүлнэ гэдгийг бүх хүн харна.

Би бол бүх хүний зүрх сэтгэлийн гүнийг байнга шинжилдэг Нэгэн. Намайг зөвхөн гаднаас бүү хар. Сохор хүмүүс! Миний маш тодорхой хэлсэн үгийг та нар

сонсдоггүй, бүрэн төгс Бурхан Өөрөө Надад ердөө итгэдэггүй. Намайг аргалж, Надаас аливааг нууж зүрхэлдэг хэнийг ч Би тэвчихгүй нь лавтай.

Чи Миний айлдвар нэг бүрийг санаж байна уу? “Намайг харна гэдэг нь нуугдмал нууц нэг бүрийг мөнхөөс мөнхөд харахтай адил.” Чи энэ үгийг анхааралтай тунгаан бодсон уу? Би бол Бурхан, Миний нууцууд та нарт харагдсан. Та нар хараагүй гэж үү? Яагаад Надад анхаарал тавьдаггүй юм бэ? Оюун ухаандаа байгаа тодорхойгүй Бурханыг яагаад тийм их шүтдэг юм бэ? Нэгэн жинхэнэ Бурхан Би ямар нэгэн буруу зүйл хийж яаж болох юм бэ? Үүнийг тодорхой хар! Үүнд итгэлтэй бай! Миний үг, үйлдэл бүр, Миний үйл хэрэг, хөдөлгөөн болгон, Миний инээмсэглэл, хооллолт, хувцаслалт, Миний бүх зүйлийг Бурхан Өөрөө хийдэг. Та нар Намайг шүүдэг: Намайг ирэхээс өмнө та нар Бурханыг хэдийнээ харсан юм гэж үү? Тэгээгүй юм бол оюун санаандаа яагаад Намайг өөрсдийнхөө Бурхантай үргэлж харьцуулдаг юм бэ? Энэ нь бүхэлдээ хүний үзлийн үр дүн! Миний үйлдэл, зан авир та нарын төсөөлөлтэй нийцдэггүй, тийм үү? Миний үйлдэл, зан авир зөв эсэх талаар саналаа хэлэхийг Би хэнд ч зөвшөөрөхгүй. Би бол нэгэн жинхэнэ Бурхан, энэ бол өөрчлөгдөшгүй, хөдөлшгүй үнэн! Өөрийнхөө заль мэхэнд бүү авт. Миний үг үүнийг туйлын тодорхой хэлчихсэн. Надад хүн чанарын өчүүхэн хэсэг ч байхгүй; Би бүхэлдээ Бурхан Өөрөө бөгөөд юу ч нуулгүйгээр та нарт бүрэн үзэгдсэн!

72-Р БҮЛЭГ

Хэрвээ чи аливаа дутагдал, сул талаа олж илрүүлбэл үүнээс ангижрахын тулд даруйхан Надад найдах ёстой. Бүү хойшлуул; эс тэгвээс Ариун Сүнсний ажил чамаас хэтэрхий хол байж, чи маш хол хоцорно. Ойр ойрхон Надад ойртож, залбирч, Миний өмнө нөхөрлөл хийснээр л Миний даалгасан ажлыг гүйцэтгэж болно. Эдгээр зүйлийг хийхгүй бол ямар ч үр дүнд хүрэхгүй бөгөөд бүх зүйл талаар өнгөрсөн байх болно. Миний өнөөдрийн ажил урьдынхтай адил биш; Миний хайрладаг хүмүүсийн амийн хэмжээ урьдынхаас асар өөр. Тэд бүгд Миний үгийг тодорхой ойлгож, нэвтэрхий мэддэг. Энэ бол хамгийн илэрхий тал бөгөөд Миний ажлын гайхамшгийг хамгийн сайн тусгаж чаддаг. Миний ажлын хурд нэмэгдсэн бөгөөд энэхүү ажил урьдынхаас гарцаагүй ялгаатай. Хүмүүсийн хувьд үүнийг төсөөлөхөд хэцүү, ойлгож ухаарах бүр ч боломжгүй. Та нарт юу ч цаашид нууц биш; харин ч бүгд мэдэгдэж, харагдсан. Энэ нь илэрхий, чөлөөлөгдсөн, түүнчлэн бүрэн эрх чөлөөтэй. Миний хайрладаг хүмүүс мэдээж аливаа хүн, үйл явдал, зүйл, эсвэл аливаа орон зай, газар зүйд хязгаарлагдахгүй; тэд бүх орчны тулгасан хяналтыг даван дийлж, махан биеэс гарч ирнэ. Энэ бол Миний агуу ажлын биелэлт юм. Дараа нь хийх зүйл юу ч үлдэхгүй; бүрмөсөн дуусна.

Агуу ажлын биелэлтийг бүх ууган хөвгүүн болон Миний хайрладаг бүх хүнд хамаатуулан дурддаг. Үүнээс хойш та нар аливаа хүн, үйл явдал, зүйлд

хянагдахгүй. Та нар орчлон ертөнцийн янз бүрийн улс орноор аялж, бүхий л сансар огторгуйг хөндлөн гулд туулж, өөрсдийн мөрийг хаа сайгүй үлдээнэ. Үүнийг хол байна гэж бүү бод; энэ бол тун удахгүй хоёр нүдний чинь өмнө биелэх зүйл юм. Миний хийдэг зүйлийг та нарт даалгаж, Миний алхдаг газруудад та нарын мөр гарна. Түүнчлэн, энэ бол та нар Надтай хамт хаанчлахын жинхэнэ утга учир билээ. Миний өгдөг илчлэл яагаад өчүүхэн ч нуугдмал байлгүйгээр, улам бүр тодорхой, улам бүр ойлгомжтой болж байгааг тунгаан бодож үзсэн үү? Яагаад Би хамгийн өндөр гэрчлэл хийж, бүх нууц болон бүх үгийг та нарт хэлсэн байх вэ? Шалтгаан нь дээр дурдсан ажлаас өөр юу ч биш. Гэсэн ч, та нарын одоогийн ажлын ахиц дэндүү удаан байна. Та нар Миний алхмуудтай хөл нийлүүлж чаддаггүй, Надтай маш сайн хамтран ажиллаж чаддаггүй, мөн одоохондоо Миний хүслийг биелүүлж чадахгүй байсаар л байна. Би та нарыг илүү эрчимтэй сургаж, та нарыг бүрэн төгс болгохоор яаравчлах ёстой, ингэснээр та нар Миний зүрх сэтгэлийг аль болох хурдан хангалуун байлгаж чадна.

Одоогоор хамгийн илэрхий байгаа зүйл бол ууган хөвгүүдийн бүлэг бүрэн бүрдсэн. Бүгд Надаар хүлээн зөвшөөрөгдөж, дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш Надаар урьдчилан тогтоогдож, сонгогдсон. Тэгээд дор бүрнээ Миний Өөрийн гараар өргөгдсөн юм. Үүнийг хүн анхааран авч үзэх хэрэггүй. Энэ нь чиний хяналтаас давдаг. Бардам бүү бай; энэ бүхэн Миний сайхан сэтгэл, энэрэл юм. Миний үзэл бодлоор бол, бүх зүйл хэдийнээ гүйцэлдсэн. Та нарын нүд л хэтэрхий их бүрэлзэж байгаа бөгөөд одоо ч гэсэн та нар Миний үйл хэргийн гайхамшгийг тодорхой харж чаддаггүй. Та нар Миний бүхнийг чадагч байдал, Миний мэргэн ухаан, Миний үйлдэл, эсвэл үг, үйл хэрэг бүрийг тов тодорхой мэддэггүй, үнэхээр ойлгодоггүй. Тиймээс Би тодорхой ярьдаг. Өөрийн хөвгүүд, Өөрийн хайртай хүмүүсийн төлөө Би бүх төлөөсийг төлж, шаргуу хөдөлмөрлөж, Өөрийгөө зарлагадахад бэлэн байна. Чи Миний үгээр дамжуулан Намайг мэддэг үү? Би чамд илүү тодорхой хэлэх хэрэгтэй юү? Цаашид замбараагүй бүү бай; Миний зүрх сэтгэлд хайхрамжтай бай! Ийм агуу нууцыг та нарт хэлсэн байхад та нар юу хэлэх юм бэ? Чамд гомдол байсаар байна уу? Хэрвээ чи төлөөс төлж, шаргуу ажилладаггүй бол Миний туулсан бүх уйгагүй хичээл чармайлтыг хүртэхэд зохистой байна гэж үү?

Одоо үед хүмүүс өөрсдийгөө хянаж чаддаггүй. Миний ивээдэггүй хүмүүст хэчнээн хүссэн ч гэсэн Намайг гэх хайр төрдөггүй. Харин Миний урьдчилан тогтоож, сонгосон хүмүүс хүссэн ч гэсэн зугтаж чадахгүй; тэд хаашаа ч явсан, Миний гараас зугтаж чадахгүй. Энэ нь Миний сүр жавхлан, үүнээс ч илүүтэйгээр Миний шүүлт юм. Бүх хүн Миний төлөвлөгөө, Миний хүслийн дагуу ажил хэргээ явуулах ёстой. Энэ өдрөөс эхлээд гарцаагүй бүх зүйл Миний гарт эргэн ирдэг, энэ нь өөрсдийнх нь хяналтаас давсан байдаг. Би бүх зүйлийг хянаж, зохицуулдаг. Хэрвээ хүмүүс аар саар арга замаар оролцвоос Би тэднийг амархан тавьж явуулахгүй. Өнөөдрөөс эхлээд Би Өөрийгөө—бүхнийг бүтээсэн, хүмүүсийн дунд ирж, тэдэнд гологдож,

гүжирдүүлсэн, бүхнийг хянаж, зохицуулдаг цорын ганц жинхэнэ Бурхан, хаанчлалыг хариуцдаг Хаан, сансар огторгуйг удирддаг Бурхан Өөрөө, түүнчлэн хүмүүсийн амьдрал, үхлийг хянадаг, Үхэгсдийн орны түлхүүрийг атгадаг Бурханыг бүх хүнд мэдэгдэж эхэлнэ. Би бүх хүнд (сүнстэй ч бай, үгүй ч бай, эсвэл мунхаг ч бай, хөгжлийн бэрхшээлтэй ч бай, насанд хүрэгчид, хүүхдүүд гэх зэрэг) Өөрийгөө мэдүүлнэ. Би энэ ажлаас хэнийг ч чөлөөлдөггүй; энэ бол хамгийн хэцүү ажил, Миний сайтар бэлдсэн, яг одоогоос эхлэн хэрэгжиж байгаа ажил юм. Миний хэлдэг зүйл биелнэ. Сүнслэг нүдээ нээж, хувийн үзлээ орхиж, Би бол орчлон ертөнцийг захирдаг цорын ганц жинхэнэ Бурхан гэдгийг тань! Би хэнээс ч нуугддаггүй, хүн бүр дээр захиргааны зарлигаа хэрэгжүүлдэг.

Өөрийнхөө бүх зүйлийг хойш тавь. Надаас олж авдаг зүйлс чинь илүү их үнэ цэнтэй, хавьгүй илүү ач холбогдолтой биш гэж үү? Тэд болон чиний хогны хоорондтэнгэр газар шиг ялгаа байдаггүй гэж үү? Хэрэгцээгүй бүх зүйлийг цаг алдалгүй хая! Ерөөл хүртэх үү, золгүй явдалтай учрах уу гэдэг чинь одоо шийдэгдэж байна. Энэ бол чухал агшин; тэр ч бүү хэл хамгийн шийдвэрлэх чухал агшин. Чи үүнийг үнэхээр харж чадах уу?

73-Р БҮЛЭГ

Намайг ярьмагц Миний үг нэн даруй биелдэг; хэзээ ч өөрчлөгддөггүй ба туйлын зөв байдаг. Үүнийг санаж яв! Миний амнаас гарсан үг, хэллэг нэг бүрийг анхааралтай авч үзэх ёстой. Илүү их анхааралтай бай, чи хохирол амсаж, Миний шүүлт, Миний уур хилэн, Миний шатаалтыг л хүлээн авах вий. Миний ажил одоо маш хурдан хэмнэлээр явагдаж байгаа ч бүдүүвч төдий бус; үүнийг маш нарийн боловсруулсан болохоор энгийн нүдэнд бараг харагдахгүй бөгөөд хүний гар хүрч чадахгүй. Энэ нь тун нягт нямбай. Би хэзээ ч хоосон үг айлддаггүй; Миний хэлдэг бүхэн үнэн. Миний үг бүр жинхэнэ, алдаа мадаггүй гэдэгт чи итгэх ёстой. Болгоомжгүй бүү бай; энэ бол чухал агшин! Ерөөл хүртэх үү, золгүй явдалтай тулгарах уу гэдэг чинь яг энэ агшинд шийдэгддэг бөгөөд ялгаа нь яг л тэнгэр, газар мэт байдаг. Тэнгэр лүү явах уу, Үхэгсдийн орон руу явах уу гэдэг чинь бүхэлдээ Миний хяналтад байдаг. Үхэгсдийн орон руу явах гэж байгаа хүмүүс сүүлчийнхээ үхлийн тулааныг хийж байхад тэнгэр лүү явах гэж байгаа хүмүүс эцсийн удаа зовж, Миний төлөө эцсийн удаа зарлагадаж байгаа. Ирээдүйд тэд, хүмүүст төвөг учруулдаг шалихгүй зүйлсгүйгээр (гэрлэлт, ажил, залхмаар эд хөрөнгө, байр суурь гэх мэт) зугаацан баясаж, магтахаас өөрийг хийхгүй. Харин Үхэгсдийн орон руу явж байгаа хүмүүсийн хувьд тэдний зовлон үүрдийнх (энэ нь тэдний сүнс, сэтгэл, биеийг хэлдэг); тэд Миний шийтгэлийн гараас хэзээ ч зугтахгүй. Энэ хоёр тал гал, ус мэт нийцэшгүй юм. Тэдгээр нь огтхон ч холилддоггүй: Золгүй явдал амсдаг хүмүүс золгүй явдал амссаар байхад ерөөгдсөн хүмүүс сэтгэлээ ханатал жаргана.

Бүх үйл явдал, зүйлийг Би хянадаг, Миний хөвгүүд, Миний хайртууд болох та нар Надад бүр ч их харьяалагддаг гэдгийг дурдахын хэрэггүй. Та нар бол Миний 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөний биелэлт; Миний эрдэнэс юм. Миний хайрладаг бүх хүн Миний нүдэнд таатай байдаг, учир нь тэд Намайг харуулдаг; Өөрийн үзэн яддаг бүх хүнийг Би харах ч үгүйгээр жигшдэг, учир нь тэд бол Сатаны үр удам, Сатанд харьяалагддаг билээ. Өнөөдөр, хүмүүс бүгд өөрсдийгөө шинжлэх ёстой: Хэрвээ санаа зорилго чинь зөв бөгөөд чин сэтгэлээсээ Намайг хайрладаг бол Би чамайг хайрлах нь гарцаагүй. Чи Намайг үнэхээр хайрлах ёстой ба Намайг хуурах ёсгүй! Би бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан! Хэрвээ санаа зорилго чинь буруу, чи Надад хүйтэн хөндий, үнэнч бус хандвал Би чамайг үзэн ядах нь гарцаагүй; Би чамайг сонгоогүй, мөн урьдчилан тогтоогоогүй. Зүгээр л там руу явахаа хүлээж бай! Бусад хүмүүс эдгээр зүйлийг харж чадахгүй байж магадгүй боловч зөвхөн чи болон Би—хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг Бурхан л—эднийг мэддэг. Энэ нь тодорхой нэг цагт илчлэгдэнэ. Чин үнэнч хүн санаа зовох хэрэггүй бөгөөд чин үнэнч бус хүмүүс айх хэрэггүй. Энэ нь бүгд Миний ухаалаг төлөвлөгөөний хэсэг юм.

Даалгавар яаралтай, ярвигтай бөгөөд энэхүү эцсийн ажлыг дуусгахын тулд та нар Миний төлөө сүүлчийн удаа зарлагадах шаардлагатай. Миний шаардлагууд үнэндээ тийм ч өндөр биш: Та нар надтай маш сайн хамтран ажиллаж, бүх зүйл дээр Намайг сэтгэл хангалуун байлгаж, Миний удирдамжийг дотроо дагаж чаддаг байхад л болно. Сохор бүү бай; зорилготой байж, Миний санаа зорилгыг бүх талаас, бүх зүйл дээр мэдэхээр хичээ. Учир нь та нарын хувьд Би цаашид нууцлаг Бурхан байхаа больсон бөгөөд Миний санаа зорилгыг ойлгохын тулд та нар энэ талаар маш тодорхой мэдэх ёстой. Маш богино хугацаанд та нар үнэн замыг эрж хайдаг гадаадын хүмүүстэй уулзаад зогсохгүй, үүнээс ч чухал нь тэднийг хариулах чадвартай байх ёстой. Энэ бол Миний яаралтай санаа зорилго; та нар үүнийг харж чадахгүй бол нэмэргүй. Гэхдээ та нар бүхнийг чадагч байдалд минь итгэх ёстой. Хүмүүс зөв байгаа цагт Би тэднийг сайн цэргүүд болгон сургах нь гарцаагүй. Би бүх зүйлийг зүй зохистойгоор зохицуулсан. Та нар Миний төлөө зовохоор эрмэлзэх ёстой. Энэ бол гол чухал агшин. Үүнийг бүү алд! Би урьд нь хийсэн зүйлсийг чинь санахгүй. Та нар залбирч, Миний өмнө үргэлж гуйх ёстой; чамд эдлүүлж, ашиглуулахын тулд Би хангалттай нигүүлсэл хайрлана. Нигүүлсэл болон ерөөл нь адилхан зүйл биш. Та нар яг одоо Миний нигүүлслийг эдэлж байгаа бөгөөд Миний нүдээр бол үүнийг дурдахын ч хэрэггүй, харин ерөөл бол ирээдүйд та нарын хязгааргүй эдлэх зүйл билээ. Тэдгээр нь хүмүүст тохиолдоогүй ерөөл бөгөөд үүнийг тэд төсөөлж чадахгүй. Энэ шалтгааны улмаас Би та нарыг ерөөгдсөн гэж хэлдэг бөгөөд эдгээр нь бүтээлийн цаг үеэс хойш хүмүүсийн эдлээгүй ерөөл юм.

Би Өөрийн бүх зүйлийг та нарт аль хэдийн илчилсэн. Та нар Миний зүрх сэтгэлд хайхрамжтай байж, бүх зүйл дээр Намайг бодож, бүх талаар Надад хайхрамжтай хандаж, инээмсэглэж буй царайгаа Надад үргэлж харуулна гэж л Би найддаг.

Одоогоос эхлээд ууган хөвгүүдийн байр суурийг олж авсан хүмүүс бол Надтай хамт хаанчлах хүмүүс юм. Тэд ямар ч ахад дээрэлхүүлэхгүй, Миний цээрлүүлэлт юм уу харьцалтыг туулахгүй, учир нь Миний үйлддэг зарчим энэ: Ууган хөвгүүдийн бүлэг дэх хүмүүс бол бусдад дорд үзэгдэж, дээрэлхүүлсээр ирсэн хүмүүс бөгөөд амьдралын бүхий л сайн мууг амссан хүмүүс юм. (Би тэдэнтэй урьдчилан харьцаж, тэднийг эвдсэн, бас урьдчилан бүрэн төгс болгосон.) Энэ хүмүүс хүртэх учиртай ерөөлөө аль хэдийн Надтай хамт урьдчилан эдэлсэн. Би зөвт бөгөөд хэзээ ч, хэнийг ч алагчилдаггүй.

74-Р БҮЛЭГ

Миний үгийг уншиж, энэ нь биелнэ гэдэгт итгэдэг хүмүүс ерөөлтэй еэ. Би чамтай муухай харьцахгүй; Би чиний итгэдэг зүйлийг чиний дотор биелүүлж өгнө. Энэ бол Миний ерөөл чам дээр ирж буй нь юм. Миний үг хүн бүрийн дотор нуугдсан нууцыг яг онож цохидог. Хүн бүр үхлийн шархтай ба Би бол эдгээрийг анагаадаг сайн эмч юм: Зүгээр л Миний өмнө ир. Би ирээдүйд уй гашуу болон нулимс байхаа болино гэж яагаад хэлсэн бэ? Үүний учир нь энэ шүү дээ. Миний дотор бүх зүйл гүйцэлдсэн байдаг, харин хүмүүсийн дотор бүх зүйл завхарч, хий хоосон ба хүмүүст хуурмаг байдаг юм. Миний дэргэд чи бүх зүйлийг хүлээж авах бөгөөд төсөөлж ч чадахааргүй ерөөлүүдийг харж, мөн эдлэх болно. Миний өмнө ирдэггүй хүмүүс лав тэрслүү бөгөөд яахын аргагүй Намайг эсэргүүцдэг хүмүүс юм. Би тэднийг яав ч хялбар өршөөхгүй; ийм төрлийн хүмүүсийг Би хатуу гэсгээнэ. Үүнийг санагтун! Миний өмнө олон хүн ирэх тусам улам илүүг олж авна, гэхдээ энэ нь зөвхөн нигүүлсэл байна. Дараа нь тэд бүр ч илүү их ерөөлүүд хүлээж авна.

Дэлхийг бүтээснээс хойш Би энэ бүлэг хүмүүсийг, тухайлбал, өнөөдрийн та нарыг урьдчилан тогтоож, сонгож эхэлсэн. Та нарын зан авир, хэв чанар, гадаад төрх, биеийн хэмжээ, та нарын төрсөн гэр бүл, ажил, гэрлэлт гээд чамайг бүхэлд чинь, үс болон арьсны чинь өнгийг, мөн чиний төрөх цаг, газрыг хүртэл бүгдийг нь Би гараараа зохицуулсан. Өдөр тутам чиний хийдэг зүйлс болон уулздаг хүмүүс хүртэл Миний гараар зохицуулагдсан ба өнөөдөр чамайг Өөрийнхөө дэргэд авчрах нь ч үнэн хэрэгтээ Миний зохицуулалт гэдгийг дурдаад ч хэрэггүй. Өөрийгөө эмх замбараагүй байдалд бүү оруул; чи тайван урагшлах хэрэгтэй. Миний өнөөдөр чамд эдлүүлдэг зүйл нь чиний хүртвэл зохих хувь бөгөөд үүнийг дэлхий бүтээгдэх үед Би урьдчилан тогтоосон. Хүмүүс бүгд маш туйлшрамтгай: Нэг бол хэтэрхий гөжүүд, үгүй бол туйлын ичгүүргүй. Тэд аливааг Миний төлөвлөгөө болон зохицуулалтын дагуу хийгээд явж чаддаггүй. Цаашид ингэдгээ боль. Миний дотор бүгд чөлөөлөгдсөн; аминд чинь гарз учрах учир өөрийгөө бүү хүл. Үүнийг сана!

Бүх зүйл Миний гарт байдаг гэж итгэ. Урьд та нарт нууцлаг байсан зүйлс өнөөдөр бүгд илэн далангүй илчлэгдсэн; эдгээр нь цаашид нуугдмал биш (учир нь

Би, ирээдүйд юу ч нууц биш болно гэж хэлсэн билээ). Хүмүүс дандаа тэвчээргүй байдаг; тэд ямар нэгэн зүйлийг гүйцээх гэж хэтэрхий сандарч, Миний зүрх сэтгэлд юу байгааг анхаарч үздэггүй. Та нар Миний ачааг хуваалцаж, Миний гэр орныг зохицуулж болох тул Би та нарыг сургаж байна. Та нар дүү нараа удирдаж чадна, Эцэг, хөвгүүд бид удахгүй дахин нэгдэж, дахиад хэзээ ч салахгүй байж болох тул Би та нарыг хурдан өсөөсэй гэж хүсэж байна. Энэ нь Миний санаа зорилгыг биелүүлнэ. Нууцлаг зүйлс бүх хүнд хэдийн илчлэгдчихсэн ба юу ч нууц далд үлдээгүй: Би—хэвийн хүн чанар болон бүрэн бурханлаг чанарыг хоёуланг нь эзэмшдэг, бүрэн төгс Бурхан Өөрөө—өнөөдөр яг та нарын нүдний өмнө илчлэгдсэн. Миний бүхий л оршихуй (хувцас, гадаад төрх, биеийн хэлбэр) бол Бурханы Өөрийн төгс илрэл; энэ бол дэлхий бүтээгдсэнээс хойш хүмүүсийн төсөөлж байсан боловч хэний ч харж байгаагүй Бурханы үнэн бие юм. Миний үйлдлүүд Миний үгтэй адил сайн байдаг нь Миний хэвийн хүн чанар болон бүрэн бурханлаг чанар нэг нэгнээ гүйцээдэг учиртай; түүнчлэн энэ нь ийм үлэмж хүч эгэл хүнд байдгийг харах боломжийг бүх хүнд олгодог. Надад чин сэтгэлээсээ итгэдэг хүмүүст Би Намайг хайрлаж чадах жинхэнэ зүрх сэтгэлийг өгсөн учраас та нар Намайг хайрладаг билээ. Чамтай харьцах үедээ Би чамайг ухааруулж, гэгээрүүлдэг бөгөөд үүгээр дамжуулан Намайг мэдэх боломж олгодог. Үүний үр дүнд Би чамтай яаж ч харьцсан, чи зугтахгүй; харин Миний талаар улам бүр эргэлзээгүй болно. Чи сул дорой байх үед энэ нь ч бас Миний зохицуулалт бөгөөд Намайг орхих л юм бол үхэж, хатна гэдгийг харах боломжийг чамд олгодог. Чиний амь бол Би гэдгийг чи үүнээс мэдэж болно. Сул дорой байсныхаа дараа хүчтэй болохдоо чи сул дорой юм уу хүчтэй байх нь чамаас хамаарахгүй гэдгийг ойлгох боломжтой болно; энэ бол бүхэлдээ Миний шийдэх зүйл.

Бүх нууц бүхэлдээ илчлэгдсэн. Та нарын ирээдүйн үйл ажиллагаанд Би Өөрийн зааварчилгааг нэг бүрчлэн өгнө. Би бүрхэг байхгүй; та нар юмыг өөрсдөө бодож тунгаах хэрэггүй, тэгвэл Миний удирдлагыг үймүүлэх тул Би маш илэн далангүй байх ба тэр ч бүү хэл та нартай шууд ярина. Ийм учраас, Би үүнээс хойш юу ч нууц далд байхаа болино гэж ахин дахин онцлон тэмдэглээд байна.

75-Р БҮЛЭГ

Намайг үг хэлмэгц бүгд өчүүхэн ч зөрөөгүй биелнэ. Одоогоос эхлэн, бүх далд нууц огтхон ч нуугдаж, далдлагдахгүй бөгөөд Миний хайртай хөвгүүд та нарт илчлэгдэнэ. Би чамд Өөрийн илүү агуу тэмдэг, гайхамшгийг харуулж, бүр ч агуу нууцыг харуулна. Эдгээр зүйл та нарыг лавтай гайхшируулж, төгс хүчит Бурхан Миний талаар илүү их ойлголт өгч, энд буй Миний мэргэн ухааныг үнэлэх боломж олгоно. Өнөөдөр та нар бүтээлээс хойш хүмүүсийн хэзээ ч хараагүй нэгэн жинхэнэ Бурхантай нүүр тулан учраад байна, Надад ямар ч онцгой зүйл үгүй. Би та нартай

хамт хооллож, амьдарч, ярьж, инээдэг, бас үргэлж та нарын дотор амьдрахын зэрэгцээ та нарын дунд хөдөлдөг. Итгэдэггүй, эсвэл өөрсдийн гэсэн ноцтой үзэлтэй хүмүүст бол энэ нь бул хар чулуу болдог. Энэ бол Миний мэргэн ухаан. Би бас Өөрийн хэвийн хүн чанарын мэддэггүй зүйлсийн тухай зарим хүнд илчилнэ, гэхдээ энэ нь Би Бурхан Өөрөө биш гэсэн үг биш. Харин ч эсрэгээрээ энэ асуудал төгс хүчит Бурхан мөн гэдгийг минь нотлоход хангалттай. Итгэдэг хүмүүст энэ асуудал шийдвэрлэх үр нөлөөтэй байдаг, зөвхөн энэ асуудлаас л болж тэд Надад зуун хувь бат итгэдэг. Хэтэрхий бүү сэтгэлээ түгшээ; Би аливааг нэг нэгээр нь илчилнэ.

Та нарын хувьд Би нээлттэй бөгөөд нуугдмал биш. Гэвч хорон санаатай, тодорхой хэмжээнд Сатаны завхруулсан үл итгэгчдийн хувьд гэвэл, Би нуугдмал хэвээр үлдэнэ. Гэхдээ Би Өөрийгөө бүх хүнд илчлэх тухай урьд нь ярих үедээ Өөрийнхөө зөвт байдал, шүүлт, сүр жавхланг хэлж байсан юм, ингэснээр бүх орчлон ертөнц болон бүх зүйлийг хариуцдаг гэдгийг минь тэд хүлээн авдаг үр дүнгээсээ мэдэж авна. Зүрх зоригтой үйлд! Зүгээр л толгойгоо өргө! Бүү ай: Та нарын Эцэг—Би та нарыг дэмжих гэж энд байгаа бөгөөд та нар зовохгүй. Миний өмнө тогтмол залбирч, гуйж байгаа цагт Би та нарт бүх итгэлийг хайрлана. Эрх мэдэлтэй хүмүүс гаднаа хэрцгий мэт санагдаж болох ч бүү ай, учир нь энэ нь та нарын итгэл өчүүхнээс болж байгаа юм. Итгэл чинь өсөж байгаа цагт юу ч хэтэрхий хэцүү байхгүй. Ханатлаа баясаж, дэвхцэцгээ! Бүх зүйл та нарын хөл доор, мөн Миний атганд байна. Амжилт, сүйрэл Миний ганц үгээр шийдэгддэг бус уу?

Одоо Миний ашиглаж байгаа хүмүүс бүгд аль эрт нэг бүрчлэн Миний сайшаалыг хүртсэн юм. Өөрөөр хэлбэл, ууган хөвгүүдийн бүлэг дэх бүх хүн аль хэдийн тодорхойлогдсон бөгөөд дэлхий ертөнцийг бүтээснээс минь хойш тодорхойлогдсон байдаг. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, бүгд Миний тушаалыг дагах ёстой. Нэг ч хүн үүнийг хийж чадахгүй; энэ бүгд Миний зохицуулалт юм. Надтай хамт бүх зүйл тогтвортой, найдвартай байдаг; Надтай хамт бүх зүйл өчүүхэн ч хичээл зүтгэл шаардалгүй зохих ёсоор, зөв зүйтэй хийгдэнэ. Намайг хэлэхэд биелдэг; Намайг хэлэхэд хийгддэг. Олон улсын нөхцөл байдал үймээн самуунтай байхад та нар яагаад сургалтаа эхлэхээр яарсангүй вэ? Хэзээ хүртэл хүлээх юм бэ? Харийнхан та нартай уулзахаар Хятад руу үй олноороо ирэх өдөр хүртэл хүлээх юм уу? Та нар өмнө нь жаахан удаан байсан байж болох ч өөрсдийгөө өөгшүүлээд байж болохгүй! Миний хөвгүүд ээ! Миний уйгагүй санаа зорилгод анхаарал тавь! Надтай ойртдог хүмүүс бүхнийг илүү их олж авна. Надад эргэлзэж байна уу?

Миний ажлын алхаа бол аянгын гялбаа юм, гэхдээ яавч аянгын нүргэлэх чимээ биш. Энэ үгийн жинхэнэ утгыг ойлгож байна уу? Та нар Надтай илүү сайн хамтран ажиллаж, Миний санаа зорилгод хайхрамжтай хандаж чаддаг байх ёстой. Та нар ерөөл авахыг хүсдэг мөртөө зовлон бэрхшээлээс бас айдаг; энэ чинь та нарын хоёрдмол санаа биш үү? Чамд Би хэлчихье! Хэрвээ хүн өнөөдөр ерөөл хүлээн авахыг хүсдэг ч, тэгэхийн төлөө золиос гаргадаггүй бол шийтгэл болон Миний

шүүлтийг л хүртэнэ. Гэхдээ, золиос гаргадаг хүмүүс бүх зүйл дээр амар амгалан байж, бүх юм нь элбэг дэлбэг байх бөгөөд Миний ерөөлийг л хүлээн авна. Өнөөдөр та нарын итгэл, мөн та нар төлөөс төлөх л яаралтай хэрэгтэй байна. Миний санаа зорилгыг буруугаар бүү ойлго. Бүх зүйл өнгөрөн одно, та нар үүнийг нүдээрээ харж, биечлэн туулна. Надад ганц ч худал үг, хуурмаг зүйл байдаггүй; Миний хэлдэг бүхэн тэр чигтээ үнэн бөгөөд мэргэн ухаанаар дутдаггүй. Хагас дутуу бүү итгэ. Та нарын дунд бүхнийг гүйцэлдүүлдэг нь Би, бас мууг үйлдэгчдийг шүүж, ангилдаг нь ч Би билээ. Би та нарт хайртай, мөн та нарыг төгс болгоно. Харин тэдний хувьд бол Би шал эсрэгээрээ: ямар ч эрх чөлөөгүй, ямар ч ул мөр үлдээдэггүй үзэн ядалт, сүйрэл юм. Миний хэлдэг, хийдэг бүхэн угаасаа элбэг дэлбэг. Та нар тэдгээрийг хэсэг, хэсгээр нь судалж шинжилсэн үү? Зарим үгийг Би олон удаа хэлсэн, гэтэл та нар яагаад Миний хэлж байгааг ойлгодоггүй юм бэ? Миний үгийг уншсаны чинь дараа бүх зүйл байх ёстой байдлаараа байх уу? Тэгвэл бүх зүйл биелэх үү? Миний зүрх сэтгэлд хайхрамжтай хандах ямар ч бодол чамд алга. Би яагаад Өөрийгөө бүрэн эрх мэдэлтэй, бүхэлдээ ухаалаг, хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг нэгэн жинхэнэ Бурхан гэж хэлдэг вэ? Эдгээр үгийн утгыг бас л ойлгохгүй байна уу? Чи Миний онцолсон үг бүрийг цээжилсэн үү? Тэдгээр нь үнэхээр чиний үйлдлийн зарчим болчихсон уу?

Би бүхний дээр зогсож, бүх орчлон ертөнцийг ажигладаг. Би Өөрийн агуу хүч чадал, бүх мэргэн ухааныг улс үндэстэн, ард түмэн болгонд харуулна. Яг одоо ердөө л зугаа цэнгэл хөөхийн тулд чадах бүхнээ бүү хий. Дэлхий ертөнцийн бүх улс үндэстэн нэгдэхэд юу та нарынх биш байх вэ? Ямартай ч, Би та нарыг дутуу дулимаг байлгахгүй, бас зовоох ч үгүй. Намайг төгс хүчит Бурхан гэдэгт итгэ! Бүх зүйл гүйцэлдэж, улам бүр сайжирна! Миний ууган хөвгүүд ээ! Бүх ерөөл та нарт очно! Та нар дуусашгүй хангамжтай, баялаг, арвин, бүрэн дүүрэн тэдгээр ерөөлийг эцэс төгсгөлгүй эдэлнэ!

76-Р БҮЛЭГ

Миний айлдварууд бүгд Миний хүслийн илэрхийлэл юм. Миний ачаанд хэн анхааралтай байж чадах вэ? Миний санаа зорилгыг хэн ойлгож чадах вэ? Та нар Миний тавьсан асуулт бүрийг бодолцож үзсэн үү? Ийм хайхрамжгүй! Та нар Миний төлөвлөгөөг үймүүлж яаж зүрхлэв? Та нар хяналтаас гарчээ! Хэрэв муу ёрын сүнсний иймэрхүү ажил үргэлжилбэл Би тэднийг нэн даруй ёроолгүй нүх рүү шидэж үхүүлнэ! Би муу ёрын сүнсний янз бүрийн үйл хэргийг аль хэдийн тодорхой харсан. Муу ёрын сүнсэнд ашиглуулдаг хүмүүсийг ч бас (буруу санаа зорилготой, махан бие, эсвэл эд хөрөнгөд шунадаг, өөрсдийгөө өргөмжилдөг, чуулганыг үймүүлдэг гэх мэт хүмүүс) Би нэг бүрчлэн нэвт харсан. Муу ёрын сүнснүүдийг зайлуулмагц бүх зүйл дуусна гэж бүү бод. Би чамд хэлчихье! Одоогоос эхлээд Би энэ хүмүүсийг нэг

нэгээр нь зайлуулаад, дахин хэзээ ч ашиглахгүй! Өөрөөр хэлбэл, муу ёрын сүнсний завхруулсан ямар ч хүнийг Би ашиглахгүй бөгөөд хөөн зайлуулна! Намайг мэдрэмжгүй гэж бүү бод! Үүнийг мэдэж ав! Би бол ариун Бурхан бөгөөд бузар сүмд оршихгүй! Надад бүрэн үнэнч бөгөөд Миний ачаанд анхааралтай байж чадах шударга, ухаалаг хүмүүсийг л Би ашигладаг. Учир нь Би ийм хүмүүсийг урьдчилан тогтоосон бөгөөд бүр ямар ч муу ёрын сүнс тэдэн дээр ажилладаггүй. Би нэг зүйлийг тодорхой болгоё: Одоогоос эхлээд Ариун Сүнсний ажилгүй бүх хүн муу ёрын сүнсний ажилтай байдаг. Би дахиад хэлье: Муу ёрын сүнс ажилладаг ганц ч хүнийг Би хүсдэггүй. Тэд бүгд махан биеийнхээ хамтаар Үхэгсэдийн орон луу хаягдана!

Өмнө нь та нарт тавьсан Миний шаардлагууд бага зэрэг сул байсан ба махан биеийн тухайд та нар садар самуун байсан. Энэ өдрөөс эхлээд ингэж үргэлжлүүлэхийг чинь Би зөвшөөрөхгүй. Хэрэв та нарын үг, үйлдэл Намайг бүх талаар илэрхийлж чадахгүй бол, эсвэл Миний төрхөөс өчүүхэн төдий ч болов ялгаатай байвал Би мэдээж та нарыг амархан тавьж явуулахгүй. Эс бөгөөс, та нар эрээ цээргүйгээр байнга инээж, наргиж, тас тас хөхөрсөөр байх байсан. Чи ямар нэгэн буруу зүйл хийхдээ чамайг орхичихсон гэдгийг минь мэдэрдэггүй гэж үү? Чи мэддэг мөртөө яагаад садар самуун хэвээр байна вэ? Миний шүүлтийн гар хүрэхийг чи хүлээж байна уу? Би өнөөдрөөс эхлээд Миний санаа зорилготой нэг ч хором нийцдэггүй хэнийг ч даруй шийтгэнэ. Хэрвээ чи хов жив яриад дэмий сууж байвал Би чамайг орхино. Сүнслэг хангалт өгч чадахгүй бол бүү ярь. Би та нарыг хязгаарлах гэж үүнийг хэлээгүй, харин Миний ажил одоогийн үе шат хүртэл ахисан тул төлөвлөгөөнийхөө дагуу үргэлжлүүлнэ гэдгээ хэлж байна. Хэрвээ та нар тойрч суугаад, амийн сүнслэг зүйлсийн талаар хэлэлцвэл Би та нартай цуг байх нь гарцаагүй. Би та нарын хэнд ч шударга бус хандахгүй. Хэрэв чи амаа нээвэл Би чамд зүй зохистой үгсийг хайрлана. Чи Миний үгэн дотроос зүрх сэтгэлийг минь ойлгох ёстой. Би та нарыг хэлгүй мэт бай гэж хэлж байгаа юм биш, дэмий юм ярь гэж ч хэлж байгаа юм биш.

Тийм ч их хугацаа үлдээгүй, Миний өдөр хойшлох ёсгүй гэж Би яагаад хэлсээр байгаа юм бэ? Та нар энэ талаар анхааралтай бодож үзсэн үү? Та нар Миний үгийн утгыг үнэхээр ойлгодог уу? Өөрөөр хэлбэл, Би ярьж эхэлснээсээ хойш л ажиллаж байна. Та нар л дор бүрнээ Миний ажлын бай байсаар ирсэн. Тодорхой нэг хүн биш, түүнчлэн өөр хэн нэгэн ч биш. Та нар ерөөл эдлэх тухай л санаа зовдгоос биш, өөрсдийн амийн тухай боддоггүй. Ямар мунхаг юм бэ! Ямар өрөвдөлтэй юм бэ! Та нар Миний ачааг огтхон ч анхаардаггүй!

Миний уйгагүй хүчин чармайлт, төлсөн төлөөс бүгд та нарын төлөө байсан. Хэрэв та нар Миний ачааг хайхардаггүй бол Миний хүлээж байсан түвшинд хүрсэнгүй. Бүх үндэстэн та нарын захирахыг, бүх хүн та нарын өөрсдийг нь удирдахыг хүлээж байна. Би бүх зүйлийг та нарын гарт шилжүүлсэн. Одоо эрх мэдэлтэй хүмүүс бүгд суудлаасаа бууж, нуран унаж эхэлсэн бөгөөд Миний шүүлт

өөрсөд дээр нь буухыг л хүлээж байна. Сайн хар! Дэлхий ертөнц одоо нуран унаж байхад Миний хаанчлал амжилттай байгуулагдсан. Миний хөвгүүд гарч ирж, Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчлан, олон янзын улс үндэстэн, ард түмнийг захирч байна. Үүнийг тодорхойгүй зүйл гэж бүү бод; энэ бол илэрхий баримт. Үгүй гэж үү? Та нар Надад залбирч, Надаас гуйж эхэлмэгц Би нэн даруй арга хэмжээ авч, та нарыг хавчдаг хүмүүсийг шийтгэж, та нарыг үймүүлдэг хүмүүстэй харьцаж, та нарын үзэн яддаг хүмүүсийг устгаж, та нарт үйлчилдэг хүмүүс, үйл явдал, зүйлсийг удирдах болно. Би үүнийг олон удаа хэлсэн: Христэд үйлчлэл үзүүлдэг хэнд ч (өөрөөр хэлбэл, Миний хүүд үйлчлэл үзүүлдэг хэнд ч) Би аврал авчрахгүй. Миний Хүүд үйлчлэл үзүүлнэ гэдэг нь тэд сайн хүмүүс гэсэн үг биш; энэ нь тэр чигтээ Миний агуу хүч, гайхалтай үйл хэргийн үр дүн юм. Хүнд хэтэрхий их ач холбогдол бүү өг. Тийм хүмүүс мэдээж Ариун Сүнсний ажилгүй байдаг бөгөөд сүнслэг зүйлсийг огт ойлгодоггүй. Би тэднийг ашиглаж дууссаны дараа тэд ямар ч хэрэггүй болно. Санаж яв! Энэ бол та нарт өгөх Миний баталгаа. Бүү самгард, ойлгов уу?

Хүмүүс улам цөөрсөн ч гишүүд бүр их цэвэршүүлэгдсээр байна. Энэ бол Миний ажил, Миний удирдлагын төлөвлөгөө, түүнчлэн Миний мэргэн ухаан, Миний бүхнийг чадагч байдал. Энэ бол Миний хэвийн хүн чанар болон бүрэн бурханлаг чанарын уялдаа юм. Та нар үүнийг тодорхой харж байна уу? Та нарт үүний талаар ямар нэгэн бодитой ойлголт байна уу? Би хэвийн хүн чанарааараа хэлсэн бүхнээ бурханлаг чанарааараа дамжуулан нэг нэгээр нь гүйцэлдүүлнэ. Тийм учраас Миний хэлсэн зүйл ямар ч хоёрдмол утгагүйгээр биелнэ; харин ч бүгд тов тодорхой, илэрхий байх болно гэж Би давтан хэлсээр байгаа. Миний хэлдэг бүхэн биелэх бөгөөд хааш яаш биш байх нь мэдээж. Би хоосон үг хэлдэггүй, алдаа гаргадаггүй. Намайг хэмжих гэж зүрхэлсэн хэн ч бай шүүгдэх бөгөөд Миний гараас зугтаж чадахгүй нь лавтай. Намайг үгээ хэлмэгц хэн эсэргүүцэж зүрхлэх юм бэ? Хэн Намайг аргалж, эсвэл Надаас ямар нэгэн юм нууж зүрхлэх юм бэ? Би өмнө нь хэлсэн: Би бол ухаалаг Бурхан. Би бүх хүнийг болон сатанлаг ааш авирыг илчилж, буруу санаа зорилготой хүмүүсийг ил болгож, бусдын өмнө нэг янзаар, ар хударгаар нь өөрөөр авирладаг, Намайг эсэргүүцдэг, Надад үнэнч бус байдаг, мөнгөний араас шунадаг, Миний ачаанд анхаардаггүй, ах, эгч нараа мэхэлж, шударга бус ханддаг, хүмүүсийг баясгах гэж уран үгээр ярьдаг, ах, эгч нартайгаа нэгэн зүрх сэтгэл, оюун ухаанаар хамтран ажиллаж чаддаггүй хүмүүсийг илчлэхдээ Өөрийн хэвийн хүн чанарыг ашигладаг. Миний хэвийн хүн чанараас болж маш олон хүн Намайг нууцхан эсэргүүцэж, Миний хэвийн хүн чанарыг мэдэхгүй гэж бодоод, хууран мэхэлж, шударга бус зүйл хийдэг. Мөн маш олон хүн Миний хэвийн хүн чанарт онцгой анхаарал тавьж, Надад идэх, уух сайхан зүйлс өгч, Надад зарц мэт үйлчилж, зүрх сэтгэл дэх зүйлээ Надад ярих мөртөө Миний ар хударгаар тэс өөрөөр авирладаг. Сохор хүмүүс! Хүний зүрх сэтгэлийн гүнийг харж чаддаг Бурхан Намайг та нар хэчнээн бага мэддэг билээ. Та нар одоо ч намайг мэддэггүй; Намайг юу хийж байгааг чинь мэдэхгүй гэж бодсоор байдаг. Үүнийг бодоод үз: Миний

хэвийн хүн чанараас болж хэчнээн хүн өөрсдийгөө сүйтгэв? Сэр! Намайг дахиад бүү хуур! Чи бүх үйлдэл, ааш авир, мөн үг, үйл хэрэг бүрээ Миний өмнө тавьж, Миний шинжилтийг хүлээн зөвшөөрөх ёстой.

77-Р БҮЛЭГ

Миний үгэнд бат итгэлгүй байна гэдэг Миний үйлдэлд үгүйсгэсэн байдлаар хандахтай адил. Өөрөөр хэлбэл, Миний үг Миний Хүүгээс урсан гарсан атал та нар үүнд ач холбогдол өгдөггүй. Та нар маш хөнгөн хийсвэр юм! Миний Хүүгийн дотроос олон үг урсан гарсан боловч та нар үүнд эргэлзэж, тээнэгэлздэг. Та нар сохор юм! Миний хийсэн юм бүхний цаад зорилгыг та нар ойлгодоггүй. Өөрийн Хүүгээр дамжуулан Миний илэрхийлдэг үг Миний үг биш гэж үү? Би Өөрөө шууд хэлэх хүсэлгүй зарим зүйл байдаг тул Хүүгээрээ дамжуулан хэлдэг. Гэвч та нар яагаад тийм утгагүй аашилж, Намайг шууд яриулах гэж зүтгэнэ вэ? Та нар Намайг ойлгодоггүй, Миний үйлдэл, үйл хэрэгт үргэлж эргэлздэг! Миний хөдөлгөөн бүр, Миний үйлдэл, үйл хэрэг бүр зөв гэдгийг Би өмнө нь хэлээгүй гэж үү? Хүмүүс тэдгээрийг шинжихээ болих ёстой. Бузар гараа тат! Би чамд нэг юм хэлье: Миний ашигладаг бүх хүн Намайг дэлхийг бүтээхээс өмнө урьдчилан тогтоогдсон бөгөөд өнөөдөр бас Би тэднийг сайшаасан. Та нар байнга ийм зүйлд хүчин чармайлт гаргаж, Намайг болох хүнийг шинжиж, Миний үйлдлийг судалж байна. Та нар бүгд наймааны сэтгэлгээтэй юм. Дахиад ийм зүйл тохиолдвол та нарыг Миний гар гарцаагүй цохин унагах болно. Миний хэлж байгаа зүйл гэвэл: Надад бүү эргэлз, бас Миний хийсэн зүйлсийг битгий дүгнэн цэгнэж, эргэцүүл. Иймэрхүү зүйлд хошуу дүрж бүр ч хэрэггүй, учир нь энэ Миний захиргааны зарлигтай холбоотой юм. Энэ бол жижиг асуудал биш!

Миний зааварчилсан бүхнийг хийхийн тулд байгаа цагаа ашигла. Би бас анхааруулга болгож, дахиад хэлье: Гаднынхан Хятад руу үй олноороо орж ирэх гэж байна. Энэ бол туйлын үнэн! Ихэнх хүн үүнд эргэлзэж, бат итгэхгүй байгааг Би мэддэг тул амийн өсөлтийг хурдан эрж хайж, Миний хүслийг хурдхан хангаасай гэсэндээ та нарт ахин дахин сануулдаг. Өнөөдрөөс эхлэн, олон улсын нөхцөл байдал улам түгшүүртэй болж, янз бүрийн улс орнууд дотроосоо нуран унаж эхэлнэ. Хятадад аз жаргалтай өдөр төгсгөл болсон. Энэ нь ажилчид ажил хаяж, оюутнууд хичээл номоо хаяж, бизнес эрхлэгчид бизнес хийхээ больж, үйлдвэрүүд бүгд үүдээ барин, үйл ажиллагаагаа үргэлжлүүлж чадахгүй гэсэн үг юм. Тэдгээр албан хаагч зугтахын тулд хөрөнгөө бэлдэнэ (энэ нь ч бас Миний удирдлагын төлөвлөгөөнд үйлчилнэ), төв засгийн газрын бүх түвшний удирдагчид бүгд бэлтгэл ажил хийнгээ бусдыг золиослон байж зарим нэг зүйлд анхааранд завгүй байх болно (энэ нь дараагийн алхамд үйлчлэхийн тулд юм). Сайн харж ав! Миний ажил бүх ертөнцөд чиглэдэг тул энэ бол Хятад төдийгүй орчлон ертөнцийг бүхэлд нь

хамарсан зүйл юм. Гэхдээ энэ нь бас ууган хөвгүүд болох бүлэг хүнээс хаад бий болгох үйлчлэлийн төлөө юм. Та нар үүнийг тодорхой ойлгов уу? Түргэхэн эрж хай! Би та нарт шударга бус хандахгүй; Би та нарт ханатлаа баяр цэнгэл эдлэх боломж олгоно.

Миний үйлдэл гайхамшигтай. Дэлхий дээр агуу гамшгууд гарч ирж, бүх мууг үйлдэгч болон эрх баригч шийтгэл хүртэж байх үед—бүр нарийн хэлбэл, Миний нэрийн гаднах мууг үйлдэгчид зовох үед—Би та нарт ерөөлөө хайрлаж эхэлнэ. Энэ бол урьд нь Миний ахин дахин хэлсэн “Та нар гамшгийн зовлон шаналал, хор хөнөөлийг амсахгүй нь лавтай” хэмээх үгийн бодит утга юм. Үүнийг та нар ойлгож байна уу? “Энэ удаад” гэж Миний хэлдэг нь Миний амнаас үг гарах үеийг хэлж байгаа юм. Ариун Сүнсний ажил маш хурдан хийгдсэн; Би нэг минут, нэг секунд ч үрж, цаг алдахгүй. Харин ч хэлсэн яг тэр мөчдөө Өөрийн үгийн дагуу үйлдэх болно. Хэрэв Би, өнөөдөр хэн нэгнийг таягдан хаяна, жигшинэ гэж хэлбэл тухайн хүн даруй дуусах болно. Өөрөөр хэлбэл, Миний Ариун Сүнс тэднээс даруй явснаар тэд амьд үхдэл, хэрэггүй болно. Тийм хүмүүс амьсгалж, алхаж, ярьсан хэвээр байж болох ч, Миний өмнө залбирсаар байж болох ч Намайг өөрсдийг нь орхисон гэдгийг хэзээ ч ухаарахгүй. Тэд мөн чанартаа хэрэггүй хүмүүс байх болно. Энэ бол туйлын үнэн агаад жинхэнэ юм!

Миний үг Намайг болох хүнийг төлөөлдөг. Үүнийг санаж яв! Бүү эргэлз; гарцаагүй бат итгэлтэй байх ёстой. Энэ бол үхэл, амьдралын асуудал! Энэ бол туйлын ноцтой зүйл! Намайг үгээ хэлэх яг тэр мөчид Миний хийх гэсэн зүйл аль хэдийн биелсэн байдаг. Энэ бүх үг Миний Хүүгээр дамжин хэлэгдэх ёстой. Та нарын хэн чинь энэ асуудлын тухай нухацтай бодож үзсэн бэ? Үүнийг Би яаж өөрөөр тайлбарлаж болох вэ? Үргэлж аймхай, хулчгар байхаа боль. Би үнэхээр хүмүүсийг сэтгэлийг хайхардаггүй гэж үү? Би Өөрийн сайшаадаг хүмүүсийг тоомжиргүй хөсөр хаяна гэж үү? Миний хийдэг бүхэн зарчимтай. Би Өөрийнхөө байгуулсан гэрээг урж хаяхгүй, Өөрийн төлөвлөгөөнд ч бас саад хийхгүй. Би та нар шиг гэнэн биш. Миний ажил бол агуу зүйл; энэ бол нэг ч хүний хийж чадахгүй зүйл. Би Өөрийгөө зөвт агаад Намайг хайрладаг хүмүүст Би бол хайр гэж хэлсэн. Чи үүнийг үнэн гэдэгт итгэхгүй байна уу? Чи болгоомжилсон хэвээр байна! Бүх зүйлийн талаарх мөс чанар чинь цэвэр л юм бол чи яагаад тэгтлээ айсан хэвээр байгаа юм бэ? Чи өөрийгөө хүлчихсэн учраас тэр. Хүү минь! Бүү гунигла, нулимс бүү унага, Би чамайг хаяхгүй гэж олон удаа сануулсан. Чи надад итгэж чадахгүй л байна уу? Би чамаас зуурч, тавьж явуулахгүй; Би чамайг үргэлж Өөрийн хайраар тэвэрнэ. Би чиний Эцэг, чамайг тулж түшдэг нэгэн гэдгээ харуулахын тулд чамайг харж хандан, хамгаалж, бүх зүйл дээр чамд илчлэл, мэдлэг ухаан өгнө. Эцгийнхээ мөрөн дээрх ачааг яаж хөнгөрүүлж болох вэ гэж үргэлж бодлогоширч явдгийг чинь Би мэднэ. Энэ бол Миний чамд өгсөн ачаа юм. Үүнээс зайлах гэж бүү оролд! Өнөөдөр хэчнээн хүн Надад үнэнч байж чадах вэ? Чи бэлтгэлээ түргэсгэж, хурдан өсөж том болон, Миний зүрх сэтгэлийг хангалуун болгоно гэж Би найдаж байна. Эцэг нь хүүгийнхээ

төлөө өдөр шөнөгүй махран хөдөлмөрлөдөг тул хүү нь ч бас Эцгийнхээ удирдлагын төлөвлөгөөг минут, секунд бүрд бодолцох хэрэгтэй. Энэ бол Миний ярьдаг байсан, Надтай идэвхтэй хамтран ажиллаж байгаа хэрэг юм.

Бүгд Миний хийж байгаа хэрэг. Би өнөөдөр ашигладаг хүмүүстээ ачаа үүрүүлж, мэргэн ухаан өгнө, ингэснээр тэдний бүх үйлдэл Миний хүсэлд нийцэж, Миний хаанчлал биеллээ олж, шинэ тэнгэр, газар гарч ирнэ. Миний ашиглахгүй байгаа хүмүүс бол шал эсрэгээрээ байдаг; тэд үргэлж манарсан байдалтай, идмэгцээ унтаж, унтаж дуусаад л идэж, ачаа гэж юуг хэлдгийг огт мэддэггүй. Ийм хүмүүст Ариун Сүнсний ажил байдаггүй бөгөөд тэднийг Миний чуулганаас аль болох хурдан цэвэрлэх хэрэгтэй. Одоо Би үзэгдэлтэй холбоотой зарим асуудлыг ярилцана: Чуулган бол хаанчлалын урьдач нөхцөл; чуулган тодорхой хэмжээнд байгуулагдсан цагт л хүмүүс хаанчлалд орж чадна. Хаанчлалд хэн ч шууд орж чадахгүй (Миний амлалтыг аваагүй л бол). Чуулган бол анхны алхам боловч хаанчлал бол Миний удирдлагын төлөвлөгөөний зорилго юм. Хүмүүс хаанчлалд ормогц бүх зүйл хэлбэрээ олох бөгөөд айх зүйлгүй болно. Одоо Миний ууган хөвгүүд л Миний хамтаар хаанчлалд орж, бүх улс үндэстэн, ард түмнийг захирч эхлээд байна. Өөрөөр хэлбэл, Миний хаанчлал эмх журамд орж эхэлж байгаа бөгөөд хаад, эсвэл ард түмэн байх бүх хүн ил тод зарлагдлаа. Ирээдүйн үйл явдлыг та нарт алхам алхмаар, дэс дараалалтай хэлж өгөх болно; хэтэрхий сэтгэлээ чилээж, санаа зовох хэрэггүй. Миний чамд хэлсэн үг бүрийг санадаг уу? Хэрэв чи үнэхээр Миний төлөө байдаг бол Би чамд үнэнч шударгаар хэлэх болно. Харин ов мэх гаргаж, шударга бус авирладаг хүмүүст Би эргүүлээд хааш яаш хандаж, тийм зан авир яг хэнийг сүйрүүлэхийг тодорхой харуулна!

78-Р БҮЛЭГ

Ажлыг хийж байгаа нь Би болохоос хэн нэгэн хүн биш гэж Би өмнө нь хэлсэн. Надтай байхад бүх зүйл тайван, жаргалтай байдаг бол та нартай байхад аливаа зүйл их өөр байдаг; та нар юу ч хийсэн маш их хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Би сайшаасан бүхнээ гарцаагүй биелүүлж, Өөрийн сайшаасан хэнийг ч болов төгс болгоно. Хүмүүсээ: Миний ажилд бүү хошуу дүр! Та нар Намайг дагаж, Миний хайрладаг зүйлийг хийн, Миний үзэн яддаг бүхнээс татгалзаж, өөрсдийгөө нүглээс татан гаргаад, Миний хайрын тэврэлтэд орж байхдаа л үйлдэх хэрэгтэй. Би та нарт онгирч байгаа юм биш, бас дэгсдүүлж байгаа ч юм биш; энэ бол чухам үнэн. Хэрэв Би дэлхийг сөнөөнө гэж хэлбэл, та нарыг нүд ирмэхийн зуурт дэлхий үнсэн товрог болно. Та нар ихэнхдээ хэтэрхий сэтгэлээ чилээж, өөрсдөдөө ачаа нэмж, Миний үг хоосон байх вий гэж гүнээ айдаг. Тиймээс Надад “гарах гарц олох” гэж гүйцгээдэг. Сохрууд! Мунхгууд! Чи өөрийнхөө үнэ цэнийг ч мэдэхгүй байж Миний зөвлөх болох гэж оролддог. Чи үнэ цэнтэй гэж үү? Толинд сайн хар даа!

Би чамд нэг юм хэлье! Аймхай хулчгар хүмүүсийг хулчгар байсных нь төлөө гэсгээх ёстой, харин дээд зэргийн итгэгчид итгэлийнхээ төлөө ерөөл хүртэнэ. Тодруулбал, яг одоо хамгийн чухал асуудал нь итгэл юм. Та нарт ирэх ерөөл илчлэгдэхээс өмнө та нар яг одоо Миний төлөө зарлагадахын тулд бүхнээ золиослох хэрэгтэй. Энэ бол “ерөөл хүртэх”, “гай зовлон амсах” гэдэгт хамаарах чухамхүү тэр тал юм. Хөвгүүд минь! Миний үгс зүрх сэтгэлд чинь хадаатай хэвээр байна уу? “Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүмүүсийг Би асар ихээр ерөөх нь гарцаагүй.” Өнөөдөр чи үүний дотор орших утга учрыг үнэхээр ойлгож байна уу? Би хоосон үг хэлдэггүй; одоогоос эхлэн нуух зүйл үгүй болно. Өөрөөр хэлбэл, Миний үгэнд нуугдаж байсан зүйлсийг одоо та нарт нэг нэгээр нь, ямар ч нууж далдлах зүйлгүйгээр хэлнэ. Түүнчлэн, үг бүрд Миний үнэн утга агуулагдах бөгөөд Миний өмнө нуугдсан байсан бүх хүн, үйл явдал, аливаа зүйлийг илчлэх нь хялбар бүтэж, Надад хэцүү байхгүй гэдгийг дурдах нь илүүц биз. Миний хийдэг бүхэн Миний хэвийн хүн чанарын тал, мөн Миний бүрэн бурханлаг чанарын талыг агуулдаг. Та нар эдгээр үгийг үнэхээр тодорхой ойлгов уу? Ийм л учраас чамайг хэтэрхий яарах хэрэггүй гэж Би давтсаар байдаг юм. Хүн, эсвэл аливаа зүйлийг илчлэх Надад хэцүү биш, бас үүнд цаг үргэлж олдоно. Тийм биш гэж үү? Миний өмнө маш олон хүн үнэн төрхөө илчилсэн. Миний хийдэг бүхэн төлөвлөгөөний минь нэг хэсэг учраас тэдний сүнс үнэг, нохой, эсвэл чоно ч бай, бүгд Миний тогтоосон тодорхой цагт үнэн төрхөө илчилдэг. Та нар энэ санааг тов тодорхой ойлгох ёстой!

“Цаг тун ойрхон байна” гэсэн нь юуг хэлж байгааг чи үнэхээр ойлгож байна уу? Өнгөрсөн үед, энэ нь Миний өдрийг хэлж байна гэж чи үргэлж боддог байсан боловч та нар бүгд Миний үгийг өөрсдийн үзэлд тулгуурлан тайлбарлаж байсан. Чамд Би хэлчихье! Одоогоос эхлээд Миний үгийг буруугаар тайлбарлах хэн ч болов эргэлзээгүй хөгийн этгээд мөн! “Цаг тун ойрхон байна” гэх Миний айлдсан үг та нарын ерөөл эдлэх өдөр; өөрөөр хэлбэл, бүх муу ёрын сүнс устгагдаж, Миний чуулганаас хөөгдөж, аливааг хийх хүний бүх аргаас татгалзах өдрүүдийг хэлдэг. Түүнчлэн агуу гамшиг буун ирэх өдрүүдийг уг хэллэг илэрхийлдэг. Үүнийг санаж яв! Энэ нь бүх агуу гамшиг юм; цаашид бүү буруугаар ойлго. Миний агуу гамшгууд бүхий л дэлхий ертөнц дээр Миний гараас нэгэн зэрэг буун ирэх болно. Миний нэрийг олж авсан хүмүүс ерөөгдөж, энэ зовлонг амсахгүй гэдэг нь гарцаагүй. Та нар үүнийг одоо ч санаж байна уу? Та нар Миний ярьж байгааг ойлгож байна уу? Миний ярьдаг цаг бол чухамхүү Миний ажиллаж эхэлдэг цаг юм (агуу гамшгууд ирсэн чухам тэр мөч). Та нар Миний санаа зорилгыг үнэндээ ойлгодоггүй. Би яагаад та нарт ямар ч өршөөл үзүүлэлгүйгээр, ийм хатуу шаардлага тавьдгийг мэдэх үү? Олон улсын нөхцөл байдал хурцадмал болж, Хятадын төрийн эрхэнд байгаа (гэгддэг) хүмүүс бүх бэлтгэлээ базааж байгаа үе бол цагтай бөмбөг дэлбэрэх гэж байгаа яг тэр үе юм. Долоон улс үндэстний үнэн замыг эрж хайж байгаа хүмүүс үерийн хаалтаар орж ирэх ус шиг Хятад руу үй олноороо цөхрөлөө баран, үнэ өртгийг үл харгалзан орж ирнэ. Эдний заримыг нь Би сонгосон, өөр бусад нь Надад

үйлчлэл хийх учиртай хүмүүс боловч тэдний дунд нэг ч ууган хүү үгүй. Энэ бол Миний хийх ажил! Би дэлхийг бүтээхэд энэ аль хэдийн шийдэгдчихсэн байсан. Хүний үзлээсээ салцгаа. Намайг утгагүй зүйл ярьж байна гэж бүү таамагла! Миний бодож байгаа зүйл бол Миний аль хэдийн биелүүлчихсэн зүйл, Миний төлөвлөгөө ч мөн Миний аль хэдийн биелсэн зүйл. Та нар үүнийг тодорхой ойлгов уу?

Аливаа бүхэн бүгд Миний бодол, Миний төлөвлөгөөнд багтсан. Хүү минь! Би чиний төлөө, цаашлаад чамайг хайрладаг учраас чамайг сонгосон. Бодлоороо дуулгаваргүй байж, атаа жөтөөнд автаж зүрхэлдэг хэн ч бай Миний хараал, шатаалтаар үхэх болно. Энэ цаг үеийн хаанчлал аль хэдийн бүрэлдсэн тул энэ нь Миний хаанчлалын захиргааны зарлигтай хамаатай. Гэвч Миний хүү чи сэрэмжтэй байх учиртай ба үүнд эд хөрөнгө мэт хандаж болохгүй. Чи Эцгийнхээ зүрх сэтгэлд санаа тавьж, үүгээрээ дамжуулан Эцгийнхээ уйгагүй хичээл зүтгэлд талархах хэрэгтэй. Үүнээс, Би ямар хүнийг хамгаас их хайрладгийг, удаад нь ямар хүнийг хайрладгийг, мөн ямар хүнийг хамгаас илүү үзэн яддаг болохыг, ямар хүнд зэвүүцдэг болохыг Миний хүү ойлгож авах ёстой. Өөртөө дарамт нэмээд байх хэрэггүй. Чи ямар ч зан чанартай байсан, Миний урьдаас зохицуулсан нь тэр бөгөөд энэ нь Миний бурханлаг зан чанарын нэг талын илчлэл юм. Эргэлзээгээ хөсөр хая! Би чамайг үзэн ядах сэтгэл өвөрлөдөггүй. Яаж хэлмээр юм бэ дээ? Чи одоо ч ойлгохгүй байна уу? Чи айдастаа хүлээстэй хэвээр л байна уу? Урьд нь Миний хэлсэнчлэн, Би ариун хүмүүсийн байдлыг алган дээрээ байгаа мэт мэддэг учир хэн нь үнэнч, хэн нь урам зоригтой, хэн нь шударга, хэн нь зальхай вэ гэдгийг бүгдийг нь мэднэ.

Миний нүдээр, бүх зүйл аль эрт биелж, илчлэгдсэн. (Би бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинждэг Бурхан юм; Миний зорилго бол зүгээр л та нарт Өөрийн хэвийн хүн чанарыг үзүүлэх юм.) Гэвч та нарын өнцгөөс бүх зүйл нууцлаг, юу ч биелээгүй байгаа. Энэ нь бүхэлдээ та нар Намайг мэддэггүйгээс л болдог. Бүгд Миний гарт, бүгд Миний хөл доор байгаа бөгөөд Миний нүд бүх зүйлийг шинждэг; Миний шүүлтээс хэн зайлж чадах вэ? Бохир заваан, нуух зүйлтэй, Миний ар хударгаар шүүдэг, зүрх сэтгэлдээ эсэргүүцэл тээдэг гэх мэт Миний нүдэнд нандин гэж харагддаггүй бүх хүн Миний өмнө сөгдөж, доторхоо уудлах ёстой. Зарим хүмүүс үүнийг сонсоод багахан урам зориг орж, харин бусад нь үүнийг нухацтай авч үзэхгүй байж магад. Та нарт Би анхааруулчихъя! Ухаалаг хүмүүс түргэхэн гэмших болтугай! Хэрэв чи тэнэг хүн бол зүгээр л хүлээ! Цаг нь ирэхэд хэнд нь гай зовлон нүүрлэхийг зүгээр л харцгаа!

Тэнгэр урьдын тэнгэр хэвээр, газар ч урьдын газар хэвээрээ боловч Миний бодлоор тэнгэр газар аль хэдийн өөрчлөгдөж, урьдын тэнгэр, газар байхаа больсон. Тэнгэр гэдгээр юуг хэлж байна вэ? Мэдэх үү? Тэгвэл өнөөдрийн тэнгэр гэж юуг хэлж байна вэ? Өнгөрсөн үеийн тэнгэр гэж юуг хэлж байсан бэ? Үүнийг Би та нартай хэлэлцье: Өнгөрсөн үеийн тэнгэр гэж та нарын итгэж байсан ч, хэн нь ч харж байгаагүй Бурханыг хэлсэн бөгөөд Тэр бол хүмүүсийн чин үнэнч сэтгэлээр

итгэдэг байсан Бурхан (учир нь тэд Түүнийг харж чаддаггүй байсан). Харин өнөөдрийн тэнгэр гэдэг нь Миний хэвийн хүн чанар болон Миний бүрэн бурханлаг чанар; өөрөөр хэлбэл, энэхүү бодитой Бурханыг Өөрийг нь хэлж байгаа юм. Хоёулаа л адилхан Бурхан атал Би яагаад, Би бол шинэ тэнгэр гэж хэлдэг вэ? Энэ бүгд хүний үзэлд чиглэсэн. Өнөөдрийн газар гэдэг нь та нарын оршин байгаа газрыг хэлдэг. Өнгөрсөн үеийн газарт ариун газар нэг ч байгаагүй, харин өнөөдөр та нарын очдог газрууд ариун болж тусгаарлагдсан. Миний, энэ бол шинэ газар гэж хэлдгийн учир нь энэ юм. Энд “шинэ” гэдэг нь “ариун”-ыг хэлж байна. Шинэ тэнгэр, газар одоо бүрэн биеллээ олсон. Та нар үүнийг одоо ойлгов уу? Би та нарт бүх нууцыг хуудас хуудсаар нь илчлэх болно. Бүү яар, бүр агуу нууцыг ч та нарт илчлэх болно!

79-Р БҮЛЭГ

Сохор! Мэдлэггүй! Үнэ цэнгүй, овоолсон хог новш! Чи Миний хэвийн хүн чанарыг Миний бүрэн бурханлаг чанараас салгадаг! Та нар үүнийгээ Миний эсрэг нүгэл гэж боддоггүй юу? Тэгээд ч энэ чинь уучлахад бэрх зүйл! Өнөөдөр бодитой Бурхан та нарын дунд ирсэн боловч та нар Миний хэвийн хүн чанар гэсэн нэг л талыг мэддэг, харин бүрэн бурханлаг талыг минь огт олж хараагүй. Миний араар хэн Намайг хуурахаар оролддогийг мэддэггүй гэж чи бодоо юу? Би чамайг шүүмжлээгүй байна, би зүгээр л чамайг ямар түвшинд хүрч чадах, эцсийн эцэст хаана хүрч төгсөхийг чинь харж, ажиглаж байна. Миний үг олон мянган удаа ярьж хэлэгдсэн, гэсэн ч та нар олон муу зүйл хийлээ. Яагаад та нар Намайг хуурах гэж ахин дахин оролддог юм бэ? Амиа алдахаас болгоомжил! Хэрэв Миний уурыг тодорхой түвшинд өдөөвөл Би чамд өршөөл огт үзүүлэлгүй, чи хөөгдөн гарах болно. Би өмнө нь ямар байсныг чинь, үнэнч, зүтгэлтэй байсан эсэхийг чинь, Миний төлөө хэр их гүйж, хэчнээн зарлагадсан гэдгийг чинь харгалзаж үзэхгүй. Би эдгээр зүйлийг огт харахгүй. Чи Намайг одоо өдөх л юм бол Би чамайг ёроолгүй нүх рүү хаях болно. Намайг бас хуурахаар оролдож зүрхэлдэг хэн байна? Санаж яв! Одоогоос эхлээд Би уурлавал хэн байх нь хамаагүй, чамайг даруй зайлуулж, тэгснээр хожмын гай бэрхшээл гэж үгүй, бас чамайг дахиж харахгүй болно. Намайг эсэргүүцвэл Би чамайг тэр дор нь гэсгээнэ. Та нар үүнийг санаж явах уу? Та нар дундаас ухаалгууд нь даруй гэмших хэрэгтэй.

Өнөөдөр, өөрөөр хэлбэл, одоо Би уур хилэнтэй байна. Та нар бүгд Надад үнэнч байж, өөрийн бүх оршихуйг Надад зориулах хэрэгтэй. Дахиж хойшлуулж болохгүй. Хэрэв Миний үгийг анхаарахгүй бол Би гараа сунгаад, чамайг цохиж унагах болно. Тэгэхдээ Би бүх хүнд Өөрийгөө мэдүүлэх ба өнөөдөр Би бүгдэд уур хилэнтэй, сүр жавхлантай хандах болно (энэ нь Миний шүүлтээс ч хатуу). Би маш олон үг хэлсэн ч, та нар хариу үйлдэл огт үзүүлсэнгүй; та нар үнэхээр ийм мулгуу юм уу? Би та нарыг тийм гэж бодохгүй байна. Та нарын доторх хөгшин диавол доог тохуу хийж

байгаа нь тэр. Та нар үүнийг тодорхой хардаг уу? Эрс өөрчлөлт авчрахаар яаравчил! Өнөөдөр, Ариун Сүнсний ажил энэ үе шатанд хүртэл ахиж дэвшлээ; та нар үүнийг хараагүй юу? Миний нэр дөрвөн зүг, найман зовхист, мөн бүх улс үндэстний айлаас айлд түгж, орчлон ертөнц даяар хөгшин, залуу хүмүүс ялгаагүй ам уралдан хашхирна; энэ бол туйлын үнэн. Би бол цор ганц Бурхан Өөрөө, түүнээс гадна Би бол Бурханы цорын ганц үнэн бие, бас Би бүхэлдээ махбод, түүгээр ч зогсохгүй Бурханы бүрэн илрэл юм. Намайг хүндлэхгүй байж зүрхэлдэг, эсэргүүцэж байгаагаа харцаараа харуулж зүрхэлдэг, Намайг эсэргүүцсэн үг хэлж зүрхэлдэг хэн ч бай Миний хараал, уур хилэнгээс болж үхэх нь лавтай (Миний уур хилэнгээс хараал үүднэ). Мөн Надад үнэнч, ачлалтай биш байж зүрхэлдэг, Намайг мэхлэхээр оролдож зүрхэлдэг хэн боловч Миний үзэн ядалтаас болж үхэх нь лавтай. Миний зөвт байдал, сүр жавхлан, шүүлт үүрдийн үүрд байх болно. Эхэндээ Би элэгсэг, өршөөнгүй байсан ч, энэ нь Миний бүрэн бурханлаг зан чанар биш юм; зөвт байдал, сүр жавхлан, шүүлт л гагцхүү бүрэн төгс Бурхан Өөрөө болох Миний зан чанарыг бүрдүүлдэг. Нигүүлслийн эрин үед, Би элэгсэг, өршөөнгүй байсан. Өөрийн дуусгах ёстой байсан ажлын шаардлагаар Би хайр энэрэлтэй, бас өршөөлтэй байсан юм; гэвч дараа нь тийм байх шаардлагагүй болсон (тэр үеэс хойш огт байхгүй болсон). Миний хэвийн хүн чанар, Миний бүрэн бурханлаг чанарын хослолын бүрэн гүйцэд зан чанар нь бүгд зөвт байдал, сүр жавхлан, шүүлт юм.

Намайг мэддэггүй хүмүүс ёроолгүй нүхэнд мөхөж, Намайг бат мэддэг нь Миний хайранд халамжлуулж, хамгаалуулан үүрд амьдрах болно. Намайг нэг үг хэлэхэд бүх орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаар хүртэл дагжин чичирдэг. Миний үгийг сонсоод, айн чичрэхгүй байж хэн чадах вэ? Намайг хүндлэн мэлмэрэхээ барьж тэвчих хэн байх билээ? Хэн Миний үйл хэргээс Миний зөвт байдал, сүр жавхланг мэдэж чаддаггүй билээ! Хэн Миний үйл хэрэг дэх Миний төгс хүчит байдал, мэргэн ухааныг харж чаддаггүй билээ! Анхаарал хандуулдаггүй хэн ч бай, үхэх нь лавтай. Учир нь анхаарал хандуулдаггүй хүмүүс бол Намайг эсэргүүцдэг, Намайг мэддэггүй хүмүүс бөгөөд хамгийн дур зоргоороо тэргүүн тэнгэрэлч юм. Өөрсдийгөө шалгацгаа: Дур зоргоороо, өөрийгөө зөвтгөдөг, ихэрхүү, биеэ тоосон хэн боловч Миний үзэн ядалтын бай болж, мөхөх болно!

Одоо Би Өөрийн хаанчлалын захиргааны зарлигийг сонордуулъя: Бүх зүйл Миний шүүлт, Миний зөвт байдал, Миний сүр жавхлан дотор байдаг бөгөөд Би зөвт байдлаа бүгдэд хэрэгжүүлдэг. Надад итгэдэг гэж хэлдэг ч зүрх сэтгэлдээ Надтай зөрчилддөг, эсвэл зүрх сэтгэл нь Намайг хаясан хүмүүс бүгд Миний тогтоосон цагт хөөгдөх болно. Хүнд анзаарагдахгүй байдлаар Миний тухай егөөдөн ярьдаг хүмүүс даруй үхэх болно (тэд сүнс, бие, сэтгэлээрээ үхнэ). Миний хайрладаг хүмүүсийг дарлаж, үл тоомсорлодог хүмүүсийг Миний уур хилэн даруй шүүнэ. Өөрөөр хэлбэл, Миний хайрладаг хүмүүст атаархдаг, Намайг зөвт бус гэж боддог хүмүүсийг Өөрийн хайртай хүмүүсээр шүүлгэхээр шилжүүлэн өгнө. Төлөв томоотой, энгийн, үнэнч бүх хүн (мэргэн ухаан мөчид хүмүүсийг оролцуулаад), мөн Миний хүсэлд

гуйвшгүй чин үнэнчээр ханддаг бүх хүн Миний хаанчлалд үлдэнэ. Сургалтад хамрагдаагүй, өөрөөр хэлбэл, мэргэн ухаан, мэдлэг дутуу энэ үнэнч хүмүүс Миний хаанчлалд эрх мэдэлтэй байх болно. Гэвч тэд ч бас харьцуулж, эвдүүлж байсан. Тэд сургалтад хамрагдаагүй гэдэг нь зайлшгүй биш боловч эдгээр зүйлээр дамжуулан Би Өөрийн төгс хүчит байдал, мэргэн ухааныг хүн бүхэнд үзүүлэх болно. Надад эргэлзсээр байгаа тэр хүмүүсийг Би хөөн явуулна, Надад тэднээс ганц нь ч хэрэггүй (энэ мэт цаг үед Надад эргэлзсэн хэвээр байдаг хүмүүсийг Би жигшдэг). Бүхий л орчлон ертөнц даяар хийдэг үйл хэргээрээ Би үнэнч хүмүүст Өөрийн үйлдлийн гайхамшигт байдлыг үзүүлж, тэгснээрээ тэдний мэргэн ухаан, мэдлэг, ялган таних чадварыг хөгжүүлнэ, мөн Өөрийн гайхамшигт үйл хэргийн дүнд Би зальхай хүмүүсийг хормын дотор устгана. Миний нэрийг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрсөн бүх ууган хөвгүүн (ариун, хир толбогүй, үнэнч тэр хүмүүсийг хэлж байна) эхлээд хаанчлалд орж, бүх улс үндэстэн, бүхий л ард түмнийг Надтай хамт захирч, хаанчлалд хаан суун, хамтдаа бүх улс үндэстэн, бүх ард түмнийг шүүх болно (өөр хэнийг ч бус, хаанчлал дахь бүх ууган хөвгүүнийг хэлж байна). Бүх улс үндэстэн, бүх ард түмний дундаас шүүгдэж, гэмшсэн хүмүүс Миний хаанчлалд орж, Миний ардууд болох ба зөрүүд, гэмшдэггүй хүмүүс ёроолгүй нүхэнд (үүрд мөхөхөөр) хаягдана. Хаанчлал дахь шүүлт эцсийнх байх бөгөөд Би дэлхийг нэгд нэггүй цэвэрлэж байгаа хэрэг байх болно. Ямар ч шударга бус байдал, уй гашуу, нулимс, шүүрс алдалт гэж байхаа болино, тэр ч бүү хэл дэлхий ертөнц гэж байхгүй болно. Бүгд Христийн илрэл болж, бүгд Христийн хаанчлал байх болно. Ямар их алдар суу вэ! Хэчнээн их алдар суу вэ!

80-Р БҮЛЭГ

Гэгээрч, гэрэлтүүлэгдэхийн тулд бүх зүйл дээр Надтай бодитоор хэлэлцэх шаардлагатай; ингэснээр л сүнс амар амгалан байж чадна. Эс тэгвэл, сүнс амар амгаланг үл олно. Одоогоор та нарын дундах хамгийн хүнд өвчин гэвэл Миний хэвийн хүн чанарыг Миний бүрэн бурханлаг чанараас салгадаг явдал; түүнчлэн, та нарын олонх нь Надад бас бүрэн бурханлаг чанар байдгийг хэзээ ч мэдээгүй юм шиг Миний хэвийн хүн чанарт онцгой анхаарал хандуулдаг. Энэ чинь Намайг доромжилсон хэрэг! Та нар тэрийг мэдэх үү? Та нарын өвчин их хүнд байгаа бөгөөд эдгэрэх гэж яарахгүй бол Миний гарт үхэх болно. Миний нүүрэн дээр та нар нэг янзаар (даруу, тэвчээртэй, хүндтэй хүн мэт царай гарган) аягладаг ч Миний араар шал өөр аашилдаг (тэр чигтээ хоёр нүүртэй, замбараагүй, эрээ цээргүй байж, хүссэн бүхнээ хийж, талцаж, тусгаар хаант улсууд байгуулж, Надаас урвах гэж санаархдаг). Та нар сохорсон байна! Сатанд хууртсан нүдээ нээ! Намайг үнэхээр хэн гэдгийг хар! Чамд ичгүүр гэж алга! Миний үйлдэл гайхамшигтай гэдгийг чи мэддэггүй! Миний төгс хүчит байдлыг чи мэддэггүй! Христэд үйлчилдэг атлаа

аврагддаггүй гэж хэнийг хэлэх вэ? Чи ямар дүрд тоглож байгаагаа мэдэхгүй байна! Чи үнэндээ Миний өмнө сэтгэл татам байдлаа гайхуулж, зүсээ хувиргаж ирдэг, ичгүүргүй амьтан! Чамайг Би гэрээсээ хөөн гаргах болно; Өөрөө урьдчилан тогтоож, сонгоогүй учраас ийм төрлийн хүнийг Би ашигладаггүй.

Би хэлснээ хийдэг. Мууг үйлдэгчид айх хэрэггүй; Би ямар ч хүнд буруу зүйл хийдэггүй. Би үргэлж Өөрийн төлөвлөгөөний дагуу үйлдэж, Өөрийн зөвт байдлын дагуу аливааг үйлддэг. Мууг үйлддэг хүмүүс бүтээлээс хойш Сатаны үр удам байж ирсэн тул Би тэднийг сонгоогүй; “уул, гол шилжиж өөрчлөгддөг ч хүний уг чанар өөрчлөгдөхгүй” гэдгийн учир энэ. Хүн төрөлхтний ойлгож чаддаггүй асуудлуудын тухайд гэвэл, бүх зүйлийг тодорхой болгосон ба Надаас далд юу ч үгүй. Чи цөөн тооны хүний нүднээс юм нууж, чамгүй хүмүүсийн итгэлийг олж чадаж магадгүй ч, Надтай тэгэх амаргүй. Эцэст нь чи миний шүүлтээс зайлж чадахгүй. Хүн төрөлхтний хараа хязгаартай бөгөөд одоогийн нөхцөл байдлын багахан хэсгийг ойлгож чаддаг хүмүүс ч зарим нэгхээн чадвар эзэмшдэгт тооцогддог. Бүх зүйл Миний хяналт, зохицуулалт дор байдаг учир Миний хувьд бүх зүйл саадгүй явж, Миний замд юу ч, өчүүхэн ч болов тордоггүй. Миний хяналтад захирагдахгүй байж хэн зүрхлэх вэ! Миний удирдлагад саад болж хэн зүрхлэх вэ! Надад үнэнч бус, ачлалгүй хандаж хэн зүрхлэх вэ! Надад үнэний оргүй, худал хуурмагаар дүүрэн зүйл хэлж хэн зүрхлэх вэ! Тэдний хэн нь ч Миний хилэнт гараас зайлахгүй. Одоо чи бууж өгчихөөд, гэсгээлт хүртэж, ёроолгүй нүхэнд ороход хэчнээн бэлэн байлаа ч, Би чамайг амар өршөөхгүй. Би Өөрийн хилэнт шийтгэлийг (дээд зэргээр үзэн ядах явдал) дахин нэг амсуулахын тулд чамайг ёроолгүй нүхнээс татаж гаргана. Чамд зугтах газар байгаа юу? Миний хамгийн их үзэн яддаг зүйл гэвэл Миний хэвийн хүн чанарыг Миний бүрэн бурханлаг чанараас салгадаг явдал юм.

Надад үнэнч хүмүүс ерөөлтэй еэ; өөрөөр хэлбэл, Намайг хүний зүрх сэтгэлийг нухацтай шинжилдэг Бурхан Өөрөө мөн хэмээн үнэхээр таньдаг хүмүүс ерөөлтэй еэ. Та нарын ерөөлийг Би заавал үржүүлж, Миний хаанчлалд үүрд сайн ерөөл эдлэх боломж олгоно. Сатаныг шившиглэх хамгийн үр дүнтэй арга бас энэ юм. Гэвч, хэтэрхий бүү тэвчээр алд, бас тэсэж яд, бүх зүйлд Миний тогтоосон цаг гэж бий. Миний урьдчилан тогтоосон цаг хараахан болоогүй бол, ганц секундын өмнө байсан ч Би үйлдэхгүй. Би яг таг, хэмнэлийн дагуу үйлдэж, шалтгаангүй үйлдэл хийдэггүй. Хүн төрөлхтний бодлоор Би сэтгэл зоволгүй, Тай уул шиг тайван байдаг ч Би бол төгс хүчит Бурхан Өөрөө гэдгийг чи мэддэггүй гэж үү? Хэтэрхий бүү тэвчээргүй бай, бүх зүйл Миний гарт байна. Бүх зүйл аль эрт бэлтгэгдсэн, тэд Надад үйлчлэл хийнэ гэхээс тэсэн ядаж байна. Бүхий л орчлон ертөнц гаднаасаа эх захгүй мэт харагдах боловч Миний өнцгөөс энэ нь эмх цэгцтэй байна. Та нарт зориулж бэлдсэн бүхэн минь та нарыг л баясгахын төлөө байдаг. Үүнийг ойлгож байна уу? Миний удирдлагад бүү хутгалд. Би бүх ард түмэн, бүх улс гүрэнд Өөрийн төгс хүчит байдлыг Өөрийн үйлдлээр харуулж, Миний гайхамшигт үйл хэргийн төлөө Миний ариун нэрийг ерөөж, магтах боломж олгоно. Учир нь, хийдэг бүхэн

минь үндэслэлтэй, бүх зүйл Миний мэргэн ухаан, Миний хүч чадал, Миний зөвт байдал, сүр жавхлангаар дүүрэн, Миний уур хилэнгээр бүр ч дүүрэн байдаг гэдгийг Би хэлсэн билээ.

Миний үгийг сонсмогцоо тэр даруй сэрдэг хүмүүс Миний ерөөлийг гарцаагүй хүртэж, Миний хамгаалалт, халамжийг гарцаагүй хүлээн авна. Тэд гэсгээлтийн зовлонг туулалгүй гэр бүлийн аз жаргалыг эдлэх болно. Та нар үүнийг мэдэх үү? Зовлон бол мөнх, харин жаргал үүнээс ч мөнх; одоогоос эхлээд эдгээрийг хоёуланг нь амсах болно. Зовж байна уу, баяр хөөр амсаж байна уу гэдэг чинь нүглээ хүлээн зөвшөөрөхдөө ямар хандлага баримталдгаас чинь хамаардаг. Харин чи Миний урьдчилан тогтоож, сонгосон хүн мөн эсэх тухайд бол чи хэлсэн зүйлээсээ шалтгаалан, үүнийг бат мэдэж байх учиртай. Чи хүмүүсийг хуурч болох ч Намайг хуурч чадахгүй. Миний урьдчилан тогтоосон, сонгосон хүмүүс одоогоос эхлэн маш их ерөөгдөх болно; Өөрийн урьдчилан тогтоож, сонгоогүй хүмүүсийг Би одоогоос эхлэн хатуу гэсгээнэ. Миний та нарт үзүүлэх нотолгоо энэ. Одоо ерөөгдсөн хүмүүс эргэлзээгүй Надаар хайрлагдсан; харин гэсгээгдсэн хүмүүс Надаар урьдчилан тогтоогдож, сонгогдоогүй гэдгийг хэлэх нь илүүц биз. Үүнийг тодорхой ойлгох хэрэгтэй! Өөрөөр хэлбэл, хэрвээ одоо хүртэж байгаа зүйл чинь Миний харьцалт, Миний хатуу шүүлтийн үг бол чамайг Би зүрх сэтгэлдээ үзэн ядаж, жигшдгийнх бөгөөд чамайг хөсөр хаяна. Хэрэв Миний тайтгарал, Миний амийн хангалтыг хүлээн авдаг бол чи Миний эзэмшилд байгаа, Миний хайртай хүмүүсийн нэг юм. Чи үүнийг Миний гадаад дүр төрхөд үндэслэн тодорхойлж чадахгүй. Үүнд ухаанаа бүү гашилга!

Миний үг хүн бүрийн бодит байдлыг хэлдэг. Намайг дурын сэдвээр ярьдаг эсвэл хэлмээр санагдсан юу ч бай хамаагүй хэлдэг гэж бодоо юу? Хэрхэвч үгүй! Миний үг бүрд Миний мэргэн ухаан нуугдаастай бий. Миний үгийг үнэн л гэж авч үз. Маш ахархан хугацааны дотор, үнэн замыг эрж хайж байгаа харийн хүмүүс орж ирнэ. Тэр үед та нар гайхаж хоцрон, бүх зүйл ямар ч саадгүй бүтэх болно. Би төгс хүчит Бурхан гэдгийг мэдэхгүй байна уу? Миний энэ үгсийг сонсоод та нар тууштай итгэдэг, тийм биз? Би буруу ташаа зүйл хэлэх нь бүү хэл, алдаа гаргадаггүй. Та нар үүнийг мэдэх үү? Тиймээс, тэднийг удирдан чиглүүлж, хариулахын тулд та нар Миний сургалтыг түргэхэн хүлээн авах ёстой гэдгийг Би ахин дахин онцолсон. Үүнийг мэдэж байна уу? Та нараар дамжуулан Би тэднийг төгс болгоно. Бүр чухал нь, та нараар дамжуулан Би Өөрийн энгүй тэмдэг, гайхамшгийг харуулна, өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний дорд үздэг хүмүүсийн дундаас Би, Намайг илтгэж, Миний нэрийг алдаршуулж, Миний төлөө бүхнийг хариуцаж, Надтай хамт хаанчлах бүлэг хүнийг сонгосон юм. Иймээс, Би та нарыг одоо сургаж байгаа нь ертөнцийн хамгийн агуу удирдлага мөн; энэ бол хүн төрөлхтний биелүүлж чадахгүй гайхамшигт зүйл юм. Та нарыг төгс болгох замаар Би Сатаныг хүхэртэй галт нуур болон ёроолгүй нүх рүү хаяж, агуу улаан лууг дахин хэзээ ч босохгүй болтол үхэл рүү нь бүрмөсөн унагана. Тиймээс ёроолгүй нүхэнд хаягддаг бүхэн бол агуу улаан лууны үр удам

юм. Тэднийг Би туйлаас үзэн яддаг. Миний авчирсан зүйлийг та нар харж чадахгүй нь үү? Үнэнч шударга бус, заль мэх, арга саам хэрэглэдэг бүх хүн илчлэгдсэн. Бардам, хямсгар, өөрийгөө зөвтгөдөг, эрээ цээргүй хүмүүс бол тэргүүн тэнгэрэлчийн үр удам, Сатаны хамгийн нийтлэг жишээ агаад бүгд Миний заналт дайсан, Надтай сөргөлдөгчид юм. Би Өөрийн зүрх сэтгэл дэх үзэн ядалтыг бөхөөхийн тулд тэднийг нэг бүрчлэн шийтгэх ёстой. Би үүнийг зүйл бүрчлэн хийж, зүйл бүрчлэн шийдвэрлэнэ.

Тэгвэл хүхэртэй галт нуур болон ёроолгүй нүх гэж чухам юу юм бэ? Хүн төрөлхтөн хүхэртэй галт нуур бол биет зүйл хэмээн төсөөлдөг ч, энэ нь ихээхэн эндүү ташаа тайлбар гэдгийг хүн төрөлхтөн мэддэггүй. Гэсэн ч ой ухаанд нь энэ тодорхой байр суурь эзэлсэн хэвээр байдаг. Хүхэртэй галт нуур гэдэг нь Миний гар хүн төрөлхтөнд гэсгээлт оноох явдал; хүхэртэй галт нууранд хаягдсан хэн ч бай, Миний гарт амь үрэгдсэн байна. Энэ хүмүүсийн сүнс, сэтгэл, бие нь үүрд зовж байгаа. Бүх зүйл Миний гарт бий гэж хэлсний минь жинхэнэ утга учир энэ. Тэгвэл ёроолгүй нүх гэж юу гэсэн үг вэ? Хүний үзлээр бол үүнийг эцэс төгсгөлгүй, хэмжээлшгүй гүн гүнзгий, том ангал гэж үздэг. Жинхэнэ ёроолгүй нүх бол Сатаны нөлөө юм. Хэрэв хүн Сатаны гарт орвол ёроолгүй нүхэнд байна гэсэн үг; тэд бүр далавчтай боллоо ч гэсэн нисээд гарч чадахгүй. Ийм учраас л үүнийг ёроолгүй нүх гэдэг. Энэ хүмүүс бүгд мөнхийн гэсгээлт хүртэнэ, Би ийнхүү зохицуулсан юм.

81-Р БҮЛЭГ

Өө, энэ хорон муу, садар завхай хуучин эрин үеийг дээ! Би чамайг залгина! Сион уул аа! Намайг тунхаглахаар өндийгөөч! Миний удирдлагын төлөвлөгөө гүйцэлдэж, Миний агуу ажил амжилттай дууссаны төлөө хэн босож, уухайлахгүй байж зүрхлэх вэ! Хэн босож, баярласандаа зогсолтгүй дэвхцэхгүй байж зүрхлэх вэ! Тэгж зүрхэлсэн хүмүүс Миний гарт үхэлтэйгээ учирна! Би өчүүхэн ч энэрэл, элэгсэг сэтгэлгүйгээр, мөн тайвнаар зөвт байдлыг бүгдэд хэрэгжүүлдэг. Бүх хүн! Намайг магтаж, Надад алдар суу өгөхийн тулд босоцгоо! Миний ачаар, Надаар тогтоогдсон учраас мөнхөөс мөнх хүртэлх эцэс төгсгөлгүй алдар суу оршдог юм. Өөртөө алдар суу авч хэн зүрхлэх вэ? Миний алдар сууг биет зүйл мэт авч үзэж хэн зүрхлэх вэ? Тэгсэн хүмүүс Миний гарт хөнөөгдөнө. Өө, харгис хүмүүс ээ! Би та нарыг бүтээж, та нарыг хангаж, өнөөдрийг хүртэл та нарыг удирдан хөтөлсөн атал та нар Миний тухай өчүүхэн ч мэддэггүй, бас Намайг огт хайрладаггүй. Яаж Би та нарт дахин өршөөл үзүүлж чадах вэ? Яаж Би та нарыг аварч чадах вэ? Та нарт Би Өөрийн уур хилэнгээр хандаж л чадна! Би та нарт сүйрэл, мөнхийн гэсгээлтээр л хариу барих болно. Энэ бол зөвт байдал; үүнээс өөр байх аргагүй.

Миний хаанчлал бат бөгөөд тогтвортой; хэзээ ч нуран уналгүй, мөнх оршин тогтнох болно! Миний хөвгүүд, Миний ууган хөвгүүд, Миний ард түмэн Надтай хамт үүрдийн үүрд ерөөл эдэлнэ! Сүнслэг асуудлыг ойлгодоггүй, Ариун Сүнснээс илчлэл

хүлээн авдаггүй хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт Миний хаанчлалаас таслагдана. Тэд өөрсдийн хүслээр явахгүй, харин Миний төмөр савааны захиралт, Миний сүр жавхланд хөөгдөх бөгөөд Миний хөлөнд өшиглөгдөн гарах болно. Хэсэг хугацаанд муу ёрын сүнсэнд эзэмдүүлсээр ирсэн (төрснөөсөө хойш гэсэн үг) хүмүүс одоо бүгд илчлэгдэнэ. Би чамайг өшиглөн гаргана! Миний хэлснийг одоо ч санаж байна уу? Ариун, өө сэвгүй Бурхан Би бузар, бохир сүмд оршин суудаггүй. Муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн хүмүүс Надаар хэлүүлэлтгүй өөрсдөө үүнийг мэднэ. Би чамайг урьдчилан тогтоогоогүй! Чи хөгшин Сатан атлаа Миний хаанчлалд нэвтрэхийг хүсдэг! Яавч үгүй! Би чамд хэлж байна! Өнөөдөр Би чамд үүнийг маш тодорхой болгож өгье: Хүн төрөлхтнийг бүтээх үед Би Өөрийн сонгосон хүмүүст Өөрийн шинж чанар, Өөрийн зан чанарыг шингээсэн юм; иймээс тэд өнөөдөр Надад л үнэнч байж, чуулганы ачааг үүрч чаддаг бөгөөд өөрсдийгөө Миний төлөө зарлагадаж, бүхий л оршихуйгаа Надад зориулахад бэлэн байдаг. Миний сонгоогүй хүмүүсийг тиймээс Сатан тодорхой хэмжээгээр завхруулсан бөгөөд Миний шинж чанар, Миний зан чанарын юу ч тэдэнд үгүй. Та нар Миний үгийг зөрчилдөөнтэй гэж боддог, гэвч “Та нар Надаар урьдчилан тогтоогдож, сонгогдсон боловч үйлдлийнхээ үр дагаврыг өөрсдөө үүрдэг” гэх үг бүгд Сатаныг хэлдэг. Одоо Би нэг зүйл тайлбарлая: Өнөөдөр босож, чуулганы эрх мэдлийг авч, чуулганыг хариулж, Миний ачаанд анхаарал тавьж, онцгой үүрэг гүйцэтгэж чаддаг хүмүүс—эдгээрийн аль нь ч Христэд үйлчилж байгаа биш юм; Тэд бүгд Надаар урьдчилан тогтоогдож, сонгогдсон байдаг. Та нарыг хэтэрхий санаа зовж, амийн ахиц дэвшлээ удаашруулах вий гэсэндээ Би үүнийг хэлж байна. Ууган хүүгийн байр суурийг олж чадах нь хэд вэ? Энэ диплом авах шиг амархан хэрэг гэж үү? Байж болшгүй! Хэрэв Би та нарыг төгс болгохгүй байсан бол, та нарыг Сатан аль хэдийн тодорхой хэмжээгээр завхруулсан байх байсан. Ийм учир Би Өөрт минь үнэнч хүмүүсийг үргэлж харж хандан, хамгаалж, аюул, зовлонгоос хамгаална гэдгээ ахин дахин онцолсон юм. Миний урьдчилан тогтоогоогүй хүмүүс бол муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн, мэдрэлгүй, сүйхээгүй, сүнс нь хатсан, чуулганыг хариулж чадахгүй (урам зоригтой боловч үзэгдлийн талаар тодорхой мэдэхгүй) хүмүүс байдаг. Тэднийг Миний нүднээс хурдан далд оруулах хэрэгтэй, эртхэн байх тусмаа сайн, тэгвэл Би чамайг хараад ой гутаж, уур хилэнд автахгүй. Хэрвээ чи хурдан явбал бага гэсгээлт хүртэнэ, харин удаан байх тусам чинь гэсгээлт хатуу байх болно. Ойлгов уу? Битгий ийм ичгүүргүй бай! Чи ямар төрлийн хог шаар болохоо огт мэдэлгүй, эх захгүй, хэмжээ хязгааргүй, хайхрамжгүй, хэнэггүй байна! Сохор байна!

Миний хаанчлалд эрх баригчдыг Би бүгдийг нь хянуур сонгосон бөгөөд тэд олон удаагийн туршилтад орсон билээ; тэднийг хэн ч ялж чадахгүй. Би тэдэнд хүч чадал өгсөн тул тэд хэзээ ч унаж, эсвэл замаасаа гажихгүй. Тэд Миний сайшаалыг хүртсэн билээ. Энэ өдрөөс хойш хоёр нүүртнүүд үнэн төрхөө үзүүлнэ. Тэд бүх төрлийн гутамшигт зүйл хийж чадах ч, эцсийн эцэст Сатаныг гэсгээж, үнсэн товрог болгодог Миний гараас зайлахгүй. Миний сүм хиргүй, ариун байх болно. Энэ бүхэн

нь Надад хийх гэрчлэл, Миний илрэл, Миний нэрэн дэх алдар суу юм. Миний сүм бол Миний мөнхийн орон байр, Миний мөнхийн хайрын бай юм. Би үүнийг үргэлж хайрын гараар илбэж, хайрын үгээр тайтгаруулж, хайрын харцаар харж хандан, хайрын тэврэлтээр тэвэрдэг тул энэ нь муу ёрын нэгний занганд орж, эсвэл Сатанд мэхлэгдэхгүй. Өнөөдөр, Надад үйлчлэл үзүүлдэг боловч аврагдаагүй хүмүүс эцсийн удаа Надад ашиглуулна. Би яагаад эдгээр зүйлийг Өөрийн хаанчлалаас зайлуулах гэж яардаг вэ? Яагаад Би тэднийг Өөрийн нүднээс далд оруулах ёстой вэ? Би тэднийг ясандаа тултал үзэн яддаг! Би яагаад тэднийг авардаггүй вэ? Би яагаад тэднийг жигшдэг вэ? Би яагаад тэднийг цохиж хөнөөх ёстой вэ? Би яагаад тэднийг устгах ёстой вэ? (Тэдний ганц нь ч, бүр үнс чандруу нь ч Миний нүдний өмнө үлдэж болохгүй.) Яагаад тэр вэ? Балар эртний могой болох агуу улаан луу, бас хөгшин Сатан хүртэл Миний хаанчлалаас мөлжих санаатай байна! Мөрөөдөхөө боль! Тэд бүгд юу ч биш болж, үнс чандруу болно!

Би энэ эрин үеийг сүйрүүлж, Өөрийн хаанчлал болгон өөрчилж, Өөрийн хайрладаг хүмүүстэй хамт мөнх амьдарч, жаргах болно. Бузар зүйлс Миний хаанчлалд үлдэж чадна гэж санахын хэрэггүй. Чи булингартай уснаас загас барьж чадна гэж бодоо юу? Тийм бодлоо мартаж үз! Миний нүд бүхнийг шинжилдэг болохыг чи мэдэхгүй! Миний гар бүхнийг зохицуулдгийг чи мэдэхгүй! Өөрийгөө хэт их хүндтэй гэж бүү бод! Та нар дор бүрнээ байвал зохих байрандаа очих ёстой. Даруу мэт дүр бүү эсгэ (ерөөгдсөн хүмүүсийг хэлж байна), эсвэл битгий айж, дагжин чичир (золгүй явдал амсдаг хүмүүсийг хэлж байна). Одоо, хүн бүр зүрх сэтгэл дотроо өөрсдийгөө мэдэх учиртай. Би Өөрийн үгийг хүн бүрт хандуулдаг тул нэрээр чинь дуудаагүй ч, чи сайтар мэдэж л байх учиртай. Та нар Миний сонгосон хүн мөн эсэх нь хамаагүй, Миний үг бүгдийн чинь одоогийн нөхцөл байдалд чиглэдэг юм. Өөрөөр хэлбэл, хэрвээ та нар Миний сонгосон хүмүүсийн нэг бол Би сонгосон хүмүүсийнхээ байдлыг чиний байгаа байдалд тулгуурлан ярьдаг; харин Миний сонгоогүй хүмүүсийн хувьд гэвэл Би бас л тэдний байдалд нийцүүлэн ярьдаг. Иймээс, Миний үг тодорхой асуудлыг хөнддөг. Хүн бүр үүнийг сайн мэдрэх хэрэгтэй. Өөрсдийгөө бүү хуур! Бүү ай! Хүний тоо хязгаартай, хуруу дарам цөөхөн тул заль мэх нэмэргүй! Миний сонгосон гэж хэлсэн хүн бүр сонгогдсон бөгөөд чи хэчнээн сайн дүр эсгэлээ ч Миний шинж чанаргүйгээр бүтэлгүйтэх болно. Учир нь Би Өөрийн үгэнд хүрдэг, хайхрамж алдан Өөрийн төлөвлөгөөг нураадаггүй; Би хүссэн бүхнээ хийдэг, учир нь Миний хийдэг бүхэн зөв, Би бол хамгаас дээд, Би бол цор ганц. Та нар тодорхой мэдэв үү? Ойлгов уу?

Одоо, Миний үгийг уншсаны дараа мууг үйлддэг, шударга бус, зальхай хүмүүс ахиц дэвшил эрэлхийлж, хувийн хүчин чармайлт гаргахаар шамдан зүтгэж байна. Тэд өчүүхэн төлөөс төлөөд л Миний хаанчлалд орохоор санаархдаг. Тэд тийм бодлуудаа орхих ёстой! (Би тэдэнд гэмших боломж олгоогүй тул энэ хүмүүст найдвар гэж үгүй.) Би Өөрийн хаанчлалын үүдийг манадаг. Миний хаанчлалд хүмүүс хүссэнээрээ орж болдог гэж чи бодоо юу? Миний хаанчлал ямар ч хог

шаарыг зүгээр л хүлээн авна гэж бодоо юу? Миний хаанчлал ямар ч үнэ цэнгүй янз бүрийн хог оруулна гэж санаа юу? Тэгвэл чи эндүүрсэн байна! Өнөөдөр хаанчлал дахь хүмүүс бол Надтай хамт хааны эрх мэдэл эзэмшдэг хүмүүс; Би тэднийг хянуур боловсруулсан юм. Энэ нь зөвхөн хүсээд л хүрч болох зүйл биш—та нар Миний зөвшөөрлийг авсан байх ёстой. Энэ бол хэнтэй ч хамаагүй хэлэлцдэг зүйл биш, харин Би Өөрөө зохицуулдаг зүйл юм. Хэлсэн бүхэн минь биелдэг. Намайг хайрладаг хүмүүст Миний нууц илчлэгддэг. Мууг үйлддэг хүмүүс буюу Миний сонгоогүй хүмүүс үүнийг хүртэх гавьяагүй. Сатан тэдний чихийг таглаж, зүрх сэтгэлийг нь гартаа авч, бүх оршихуйг нь сүйтгэсэн тул тэд үүнийг сонслоо ч ойлгохгүй. Миний үйлдэл гайхамшигтай агаад ухаалаг, Би Өөрийн үйлчлэлд бүхнийг дайчилдаг гэдгийн учир юу вэ? Би Өөрийн урьдчилан тогтоогоогүй, сонгоогүй хүмүүсийг шийтгүүлж, завхруулахаар Сатанд шилжүүлэн өгөх бөгөөд Өөрөө тэднийг шийтгэхгүй; Би ийм л ухаалаг! Хэн ер нь ингэж бодож үзсэн бэ? Миний агуу ажил ямар ч хүчин чармайлтгүйгээр биелсэн, тийм биз?

82-Р БҮЛЭГ

Миний үгийг сонсоод бүгд айдаг; хүн нэг бүр айдас түгшлээр дүүрдэг. Та нар юунаас айна вэ? Би та нарыг хөнөөх гээгүй! Гэмт хүн гэлбэлзэнэ; Миний араар хийдэг зүйл чинь хөнгөн хийсвэр, бас үнэ цэнгүй. Үүнээс чинь болж Би, Өөрийн урьдчилан тогтоож, сонгоогүй хүн бүрийг ёроолгүй нүх рүү шидэж, хэдэн хэсэг бяцлахыг улайран хүстэлээ та нарыг үзэн ядахад хүрдэг. Гэвч Надад Өөрийн гэсэн төлөвлөгөө, Өөрийн гэсэн зорилго бий. Би өчүүхэн амийг чинь одоохондоо өршөөж, Надад хийх үйлчлэл чинь дуусах хүртэл чамайг хөөж явуулахгүй. Ийм амьтдыг харах хүсэл Надад үгүй; тэд Миний нэрийг гутаадаг! Үүнийг мэдэх үү? Ойлгож байна уу? Олиггүй амьтад! Үүнийг ойлгож ав! Чамайг ашигладаг нь Би, мөн чамайг ашигладаггүй нь ч бас Надаас болдог. Бүхнийг Би зохион байгуулдаг бөгөөд Миний гарт бүгд томоотой, эмх цэгцтэй байдаг. Дэг зөрчин хөдөлж зүрхэлдэг хэнийг ч Миний гар даруй хөнөөнө. Би “хөнөөнө” гэж байнга хэлдэг; үүнийг Би үнэхээр Өөрийн гараар хийдэг гэж чи бодно уу? Надад тэгэх шаардлагагүй! Миний үйлдэл хүмүүсийн төсөөлдөг шиг мунхаг биш. Миний үгээр бүх зүйл бүрэлдэж, гүйцэлддэг гэдэг нь ямар учиртай вэ? Би хуруугаа ч хөдөлгөөгүй байхад бүх зүйл гүйцэлддэг. Миний үгийн жинхэнэ утга учрыг ойлгов уу?

Надад үйлчлэл хийдэг хүмүүсийн хэнийг ч Би аврахгүй; Миний хаанчлалд тэдний хувь гэж үгүй. Учир нь энэ хүмүүс Миний хүслийг биелүүлэхийн оронд гадаад асуудлуудад л цаг заваа үрдэг. Хэдийгээр одоо Би тэднийг ашиглаж байгаа боловч, бодит байдал дээр тэд бол Миний хамгийн их үзэн яддаг, хамгаас илүү жигшдэг хүмүүс юм. Өнөөдөр, Миний хүслийг биелүүлж чадах хэнийг ч, Миний ачааг хайхарч чадах хэнийг ч, байгаа бүхнээ Надад жинхэнэ зүрх сэтгэлээр, чин

үнэнээсээ өгч чадах хэнийг ч Би хайрладаг. Тэднийг Өөрөөсөө холдуулахгүйгээр тогтмол гэгээрүүлнэ. “Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүмүүсийг Би асар ихээр ерөөх нь гарцаагүй” гэж Би байнга хэлдэг. “Ерөөнө” гэж юуг хэлж байна вэ? Чи мэдэх үү? Ариун Сүнсний одоогийн ажлын нөхцөлд энэ нь Миний чамд өгдөг ачааг хэлдэг. Чуулганы төлөө ачаа үүрч чадах, Миний төлөө өөрсдийгөө чин сэтгэлээсээ зориулдаг бүх хүний хувьд тэдний ачаа, жинхэнэ зүрх сэтгэл нь Миний хүртээсэн ерөөл билээ. Үүнээс гадна, тэдэнд Миний өгдөг илчлэл ч бас Миний ерөөл юм. Учир нь, одоо ачаагүй байгаа хүмүүсийг бол Би урьдчилан тогтоож, сонгоогүй юм; Миний хараал аль хэдийн тэдэн дээр буусан. Өөрөөр хэлбэл, Миний урьдчилан тогтоож, сонгосон хүмүүс Миний хэлсэн зүйлийн зөвхөн эерэг талаас хувь хүртдэг байхад Миний урьдчилан тогтоож, сонгоогүй хүмүүс Миний айлдваруудын сөрөг талаас л хувь хүртэж чадна. Миний үгийг олон хэлэх тусам, утга нь улам тодорхой болдог; Намайг үгээ хэлэх тусам тэдгээр нь улам тодорхой болдог. Шударга бус, зальхай, Миний урьдчилан тогтоогоогүй хүн тус бүрийг Би дэлхийг бүтээхээс өмнө хараасан юм. Та нарын төрсөн жил, сар, өдөр, бүр цаг, минут, секундийг бүгдийг нь Би тохируулан төлөвлөсөн байдаг гэж яагаад хэлдэг вэ? Уугаан хөвгүүдийн байр суурийг хэн авахыг Би эртнээс урьдчилан тогтоосон. Тэд Миний нүдэнд байдаг; Би тэднийг аль эртнээс эрхэм нандин гэж үзсэн бөгөөд Миний зүрх сэтгэлд аль эртнээс зай эзэлж ирсэн. Миний хэлдэг үг бүр жинтэй, бас Миний санааг тээдэг. Хүн юу юм бэ? Миний хайртай, ууган хөвгүүдийн байр суурьтай цөөн хүнээс гадна Миний хүслийг хайхардаг хүн хэчнээн цөөн билээ? Миний хөвгүүдийн үнэ цэнэ юу вэ? Миний ардуудын үнэ цэнэ юу вэ? Урьд “Миний хөвгүүд” гэдэг нэр томьёо нь Миний ууган хөвгүүдийн нэршил байлаа. Гэвч Миний хөвгүүд, Миний ардын ичгүүргүй хэд нь үүнийг өөрсдийг нь дуудах хүндэтгэлийн цол гэж боджээ. Миний ууган хөвгүүний дүрд ичих нүүргүйгээр бүү тогло. Энэ цолыг авах гавьяатай юу? Өнөөдөр Миний өмнө чухал байр сууринд томилогдсон хүмүүс л баталгаажсан. Тэд ууган хөвгүүдийн байр суурийг олж авсан. Тэд аль хэдийн Миний сэнтий, Миний титэм, Миний алдар суу, Миний хаанчлалаас хувь хүртсэн. Би бүх зүйлийг нягт нямбай зохицуулсан. Өнөөдөр ууган хөвгүүний байр суурийг хүлээн авсан бүх хүн, гэр бүлдээ төрсөн цагаасаа эхлээд өөрсдийнхөө ирээдүйн төлөв, ажил, гэрлэлтэд амссан зүйлс гэх мэт ихээхэн шаналал, хяхалт хавчлага, зовлон бэрхшээлийг туулсан юм. Энэ ууган хөвгүүд энэ байр суурийг ямар төлөөс төлөлгүйгээр олж авсан юм биш; харин ч тэд сайн муу, өөдөлж уруудах гээд амьдралын бүхий л эрээн барааныг туулсан. Дэлхийн хүмүүст урьд нь ихэд хүндлэгдэж, орон гэртээ тав тухтай амьдардаг байсан бүх хүн ууган хөвгүүдэд орохгүй. Тэд ууган хөвгүүд байхад тэнцэхгүй; Миний нэрд шившиг авчирдаг ба тэднийг Би огт хүсэхгүй. Миний сонгосон Миний хөвгүүд, Миний ардууд ч бас дэлхий ертөнцөд нэр хүнд сайтай боловч Миний ууган хөвгүүдийн дайд хүрэхгүй. Би одоо зарим хүнийг ашиглаж байгаа боловч тэдний дунд олон хүн Миний ард байхад ч тэнцдэггүй. Тэд бол мөнхийн шийтгэлийн зүйл; тэд Надад урт хугацаагаар

бус, түр үйлчлэл үзүүлэхээр ашиглагдаж байгаа юм. Хэн Надад урт хугацаагаар ашиглуулах вэ гэдгийг Би зүрх сэтгэлийнхээ гүнд аль хэдийн тогтоосон. Тухайлбал, чухал байр сууринд Миний томилсон хүмүүс бол Миний хайрладаг, Миний аль эртнээс ашиглаж эхэлсэн хүмүүс юм. Өөрөөр хэлбэл, тэдний үүрэг аль хэдийн шийдэгдчихсэн. Харин Миний жигшдэг хүмүүсийн хувьд гэвэл, тэд одоогийн үе шатанд түр ашиглуулж байгаагаас цаашгүй. Харийнхан ирэх үед ууган хөвгүүд та нарт тодорхой илчлэгдэнэ.

Хурдан өсөж, Миний ачаанд хайхрамжтай хандахыг Би та нараас яг одоо шаардаж байна. Энэ ачаа хэтийдсэн их биш бөгөөд Би та нараар чадах зүйлийг чинь л хийлгэнэ. Та нарын биеийн хэмжээг Би мэднэ; ямар үүрэг гүйцэтгэж чадахыг чинь мэднэ. Би энэ бүхнийг мэддэг, бас ойлгодог; Хөвгүүд минь, Би та нарыг өөрсдийгөө дуртайяа үгүйсгэж, Миний хайрладгийг хайрлаж, Миний үзэн яддагийг үзэн ядаж, Миний хийдгийг хийж, Миний хэлдгийг хэлж үнэхээр чадаасай гэж л хүсдэг. Орон зай, газар зүй, цаг хугацаа, эсвэл ямар ч хүний эрхэнд бүү ор. Та нарын сүнс газар сайгүй чөлөөтэй байж, та нар дор бүртээ Миний ууган хөвгүүдийн байр сууринд зогсож чадаасай гэж Би хүсдэг. Өнөөдөр хэн Надад бүхий л оршихуйгаа зориулдаг вэ? Хэн Миний төлөө үнэнчээр зарцуулдаг вэ? Хэн өдөр шөнөгүй Миний төлөө сэргэг байдаг вэ? Хэн Миний гэр орны ажлыг эрхэлдэг вэ? Хэн Миний төлөө мөрөн дээрх ачааг минь хөнгөлдөг вэ? Миний хөвгүүд биш гэж үү? Хийдэг бүхэн минь Өөрийн хөвгүүдийг төгс болгож, Өөрийн хөвгүүдэд үйлчлэхийн төлөө байдаг. Ойлгов уу? Бүгд Миний ууган хөвгүүдийн төлөө бөгөөд Би алдаа гаргадаггүй. Би хүмүүсийг буруу үнэлдэг гэсэн ташаа ойлголтод бүү авт, бас Би чамайг дорд үздэг гэж бүү бод. Намайг агуу авьяасыг дутуу ашигладаг гэж, эсвэл Би чамайг урьдчилан тогтоолгүй алдсан гэж бүү бод. Тийм биш; чи үүнд тэнцэхгүй! Мэдэж байна уу? Одоо Би та нарт зарим зүйлийг нотолж өгье: Миний уур хилэнг ойр ойрхон өдөөдөг, Миний шүүмжлэл, эсвэл харьцалтад үе үе өртдөг хэн ч болов Миний үзэн ядалтын бай гэдэг нь гарцаагүй. Тэд лавтай үхнэ, үүнийг өөрчлөх боломжгүй. Миний ширүүн туршилтад аль хэдийн орж, Миний сайшаалыг хүртсэн учраас Өөрийн ууган хөвгүүдтэй харьцахаа больсон гэдгээ Би хэлсэн. Миний ширүүн харцанд өртсөн хэн ч аюулд байна. Чи айхгүй байна уу? Миний амнаас үг гармагц олон хүн үхнэ. Гэвч зарим махан биеэ хадгалж үлдэнэ; тэдний ердөө л сүнс нь үхнэ. Хамгийн тодорхой үзүүлэлт нь гэвэл, тэдэнд Ариун Сүнсний ажил байдаггүй, тэднийг хязгаарлах зүйл огт үгүй. (Сатан тэднийг аль хэдийн гүн гүнзгий завхруулчихсан). Тэдний махан бие хэзээ ч устгагдлаа гэсэн, тэр нь Миний зохистой төлөвлөгөөний дагуу, Миний заасан цагт болно. Тэдний сүнсний үхэл Надад их үйлчлэл хийж чадахгүй; харин Би Өөрийн үйл хэргийн гайхамшгийг үзүүлэхдээ тэдний махан биеийг ашиглана. Үүнээс хүмүүс үнэмшинэ; тэд дуусашгүй магтаал хэлж, Намайг хүндэлдэггүй, Надаас айдаггүй хүн нэг ч байхаа болино. Би ямар ч нарийн зүйлд хөнгөн ханддаггүй; бүгд Миний төлөө үхэж, амьдрах ёстой бөгөөд Надад үйлчлэлээ хийхээс өмнө хэн ч явж болохгүй. Надад

үйлчлэлээ хийгээгүй цагт Сатан хүртэл ёроолгүй нүх рүү эргэн орж чадахгүй. Миний хийж буй алхам бүр тогтвортой, аюулгүй, бат үндэстэй байдаг. Миний хийдэг нэг ч алхам огт хуумгай байдаггүй.

Хэн Надтай эн зэрэгцэж зүрхлэх вэ? Хэн намайг эсэргүүцэж зүрхлэх вэ? Чамайг Би даруйхан цохиж унагана! Би ул мөр үлдээхгүй, чиний махан бие ор мөргүй болно; энэ маргаангүй үнэн. Би үүнийг хэлмэгцээ ажил хэрэг болгох ба ухрах зам байхгүй. Дэлхий ертөнц өдрөөс өдөрт нуран унаж, хүн төрөлхтөн өдрөөс өдөрт мөхөж байна. Миний хаанчлал өдөр өнгөрөх тусам хэлбэрээ олж, Миний ууган хөвгүүд өсөж байна. Миний уур хилэн өдөр өдрөөр ихсэж, Миний гэсгээлт улам хатуу болж, Миний үг улам ширүүсэж байна. Та нар Намайг өөрсөдтэй чинь арай зөөлөн ярьж, Миний дууны өнгө аядуу болно гэж одоо ч хүлээсээр байдаг, гэхдээ хэзээ ч бүү ингэж бод! Миний дууны өнгө хэнтэй харьцаж байгаагаас шалтгаалдаг. Өөрийн хайрладаг хүмүүст Миний дууны өнгө зөөлөн, үргэлж тайтгаруулсан байдаг бол та нарт Би зөвхөн хатуу, шүүмжлэлтэй байж, дээр нь гэсгээлт, уур хилэнгээ харуулж чадна. Хэн ч анзааргагүйгээр, дэлхийн улс орон бүрийн нөхцөл байдал улам бүр түгшүүртэй болж, өдрөөс өдөрт нуран унаж, үймээнд автаж байна. Улс бүрийн тэргүүнүүд бүгд эцэстээ эрх мэдэл олох гэж найддаг. Миний гэсгээлт тэдэн дээр аль хэдийн буучихсан гэж тэдний санаанд дааны орсонгүй. Тэд Миний эрх мэдлийг булаах гэж санаархдаг—гэвч энэ бол ердөө л хоосон мөрөөдөл! Нэгдсэн Үндэстний Байгууллагын дарга хүртэл Надаас уучлал гуйх ёстой. Түүний үйлдсэн муу үйл гэж тоймгүй. Одоо үе бол гэсгээлтийн цаг үе бөгөөд Би түүнийг зүгээр өнгөрөөхгүй. Эрх мэдэлтэй бүхэн титмээ тайлах ёстой; зөвхөн Би л бүх зүйлийг захирваас зохино. Бүх зүйл—цөөн хэдэн харийнхныг оролцуулаад бүгд Надаас шалтгаалдаг. Миний ажил аль хэдийн өдий хүрсэн учир Намайг шинжсэн хэнийг ч бай Би тэр даруй хөнөөнө. Өдөр бүр шинэ илчлэл, өдөр бүр шинэ гэрэл гарч байна. Бүх зүйл улам бүрэн төгс болж байна. Сатаны сүүлчийн өдөр улам бүр ойртож, улам тодорхой болж байна.

83-Р БҮЛЭГ

Чи Намайг төгс хүчит Бурхан гэдгийг, бүх хэрэг явдал, эд зүйл Миний хяналтад байдгийг ч мэддэггүй! Бүх зүйлийг Би бүтээж, бүрэн төгс болгодог гэдэг нь ямар учиртай вэ? Хүн бүрийн ерөөл, золгүйтэл бүгд Миний биелэлт, Миний үйлдлээс шалтгаалдаг. Хүн юу хийж чаддаг билээ? Хүн бодлоо гээд юу биелүүлж чаддаг билээ? Эх захаа алдсан энэхүү эцсийн эрин үед, тодорхой хэмжээнд Сатаны завхруулсан энэ харанхуй ертөнцөд хэд нь Миний хүсэлд нийцэж чадах вэ? Өнөөдөр ч бай, өчигдөр ч бай, эсвэл ойрын ирээдүйд ч бай хүн бүрийн амьдралыг Би тодорхойлдог. Тэд ерөөл хүлээн авах уу, эсвэл золгүйтэл амсах уу, Надаар хайрлуулах уу, эсвэл үзэн ядуулах уу гэх мэт бүх зүйл Миний ганцхан цохилтоор

нарийн шийдэгдсэн. Та нарын хэн чинь алхаагаа өөрсдөө шийддэг гэж, бас хувь заяа чинь өөрсдийн чинь гарт байдаг гэж баталж зүрхлэх вэ? Хэн тэгж хэлж зүрхлэх вэ? Хэн тийм эрээ цээргүй байж зүрхлэх вэ? Надаас айдаггүй хэн байна? Хэн зүрх сэтгэлдээ Надад дуулгаваргүй байдаг вэ? Хэн дураараа аашилж зүрхлэх вэ? Би тэднийг газар дээр нь гэсгээж, хүн төрөлхтөнд цаашид өршөөл үзүүлж, аврал хайрлахгүй. Та нар Миний нэрийг хүлээн авсан энэ удаад Би хүн төрөлхтөнд сүүлчийн удаа өршөөл үзүүлнэ. Өөрөөр хэлбэл Би, ерөөл нь мөнх биш ч гэсэн Миний нигүүлслээс ихээхэн эдэлсэн хэсэг хүнийг хүн төрөлхтнөөс сонгосон; тиймээс чамайг мөнхөд ерөөнө гэж урьдчилан тогтоогоогүй байлаа ч, Би чамд зүй бус хандахгүй бөгөөд чи шууд золгүйтэл амсах хүмүүсээс хамаагүй дээр.

Миний шүүлт үнэхээр дээд цэгт хүрч, урьд үзэгдээгүй бүс нутагт орж байна. Миний шүүлт хүн бүрд хүрэх бөгөөд энэ удаагийнх бол хилэнт шүүлт юм. Урьд нь сүр жавхлант шүүлт байсан бол одоо хамаагүй өөр. Урьд нь хүмүүс Миний илгээсэн шүүлттэй тулгарах хүртлээ өчүүхэн ч айдас мэдэрдэггүй байсан; харин одоо тэд ганц үг сонсоод л ухаан алдталаа айдаг. Зарим нь бүр Намайг амаа ангайхаас ч айдаг. Надаас дуу гарч, Намайг ярьж эхэлмэгц тэд ихэд мэгдэн, яахаа мэдэхээ больж, газрын гаваар орж, эсвэл хамгийн харанхуй мухарт нуугдан үлдэхийг чин сэтгэлээсээ хүсдэг. Ийм хүмүүс муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн тул аврагдаж чадахгүй. Би агуу улаан луу болон балар эртний могойг шүүх үед тэд хулчийж, бүр хүмүүст үзэгдэхээс ч айдаг; тэд бол харанхуйд төрсөн Сатаны үр удам үнэхээр мөн.

Би “урьдчилан тогтоолт, сонголт” зэрэг үгсийг байнга айлддаг байсан. Эдгээр үг яг ямар учиртай вэ? Би хэрхэн урьдчилан тогтоож, сонгодог вэ? Зарим хүн яагаад урьдчилан тогтоогдсон, сонгогдсон хүмүүсийн нэг биш байдаг вэ? Үүнийг чи хэрхэн ойлгож болох вэ? Энэ бүгдэд Би тодорхой тайлбар хийж, чамтай шууд ярих шаардлагатай. Хэрэв Би эдгээр зүйлийг та нарын дотор илчилсэн бол мулгуу хүмүүс үүнийг Сатаны өгсөн бодол гэж эндүүрэн итгэх байсан! Намайг хилсээр гүтгэх байсан! Одоо Би юу ч нуулгүй, илэн далангүй ярья: Би бүх зүйлийг бүтээхдээ, эхлээд хүн төрөлхтөнд үйлчлэх биет зүйлсийг (цэцэг, өвс ногоо, мод, ой шугуй, уулс, гол, нуур, хуурай газар, тэнгис, бүх төрлийн шавж, шувууд, амьтад; заримыг нь хүн төрөлхтөн идэхэд, заримыг нь хүн төрөлхтөн харахад зориулж) бүтээсэн. Өөр өөр газар нутгийн ялгаанаас хамааран янз бүрийн үр тариаг хүн төрөлхтөнд зориулан бүтээсэн; энэ бүхнийг бүтээснийхээ дараа л Би хүмүүсийг бүтээж эхэлсэн юм. Хоёр төрлийн хүмүүс байдаг: Нэг дэх нь Миний сонгож, урьдчилан тогтоосон хүмүүс; хоёр дахь нь Сатаны хэв чанартай бөгөөд энэ төрлийн хүмүүс дэлхий ертөнцийг бүтээхээс минь өмнө бүтээгдсэн боловч Сатан бүрэн завхруулсан тул Би тэднийг орхисон юм. Дараа нь Би, дор бүрнээ Миний хэв чанарыг өөр өөр түвшинд эзэмшдэг Өөрийн сонгосон, урьдчилан тогтоосон төрлийг бүтээсэн; иймээс өнөөдөр Надаар сонгогдсон хүмүүс тус бүртээ Миний хэв чанарыг өөр өөр түвшинд эзэмшдэг. Хэдийгээр тэднийг Сатан завхруулсан ч тэд Надад харьяалагддаг хэвээрээ; алхам бүр Миний удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Би бүгдийг нь

урьдаас төлөвлөсөн учир хаанчлалд үнэнч шударга хүмүүс захирдаг. Шударга бус, зальхай хүмүүс Сатаны үр төл, мөн Сатанд эзэмдүүлсэн учир хэзээ ч үнэнч байж чадахгүй; тэд бол түүний албатууд бөгөөд эхнээсээ эцсээ хүртэл түүний удирдлаган дор байдаг. Гэвч энэ бүхний зорилго нь Миний хүслийг биелүүлэх юм. Та нарын таамгийг арилгахын тулд Би үүнийг тодорхой болголоо. Би төгс болгодог хүмүүсээ халамжилж, хамгаална; харин Миний жигшдэг хүмүүсийн хувьд гэвэл үйлчлэл нь эцэс болсны дараа Миний газраас явах болно. Энэ хүмүүсийг дурдахаар Би уурлан хилэгнэж, тэднийг дурдмагц л тэр дор нь учрыг нь олчихмоор их санагддаг. Гэхдээ Би үйлдлээ хязгаарлан барьдаг; Би үйлдэл, үгээ цэгнэдэг. Би уурандаа автан дэлхий ертөнцийг дарлаж чадна, харин Өөрийн урьдчилан тогтоосон хүмүүсийг биш; тайвширсныхаа дараа Би дэлхийг Өөрийн гарын алганд атгаж чадна. Өөрөөр хэлбэл, Би бүхнийг хянадаг. Дэлхий ертөнц хүмүүсийн тэвчихээргүй хэмжээнд хүрч завхарсныг харвал Би үүнийг даруй устгана. Би ганцхан үг айлдаад л ингэж чадах бус уу?

Би бол бодитой Бурхан Өөрөө; Би ер бусын тэмдэг, гайхамшиг үйлддэггүй боловч Миний гайхамшигт үйлс хаа сайгүй байдаг. Урдах зам харьцуулшгүй илүү гэрэлтэй болох болно. Алхам бүрийн тухай Миний илчлэл бол та нарт тайлбарлах арга бөгөөд энэ бол Миний удирдлагын төлөвлөгөө юм. Өөрөөр хэлбэл, цаашид эдгээр илчлэл бүр ч олширч, улам тодорхой болно. Ойрын ирээдүйд—Мянган жилийн хаанчлалд ч гэсэн—та нар Миний илчлэлийн дагуу урагшилж, Миний мөрийг дагах ёстой. Бүгд хэлбэрээ олж, бүгд бэлтгэгдсэн; ерөөгдсөн хүмүүс та нарыг мөнхийн ерөөл хүлээж байгаа бол шийтгэгдсэн хүмүүсийг мөнхийн гэсгээлт хүлээж байна. Миний нууц та нарт хэтэрхий ихэддэг; Надад хамгийн энгийн байдаг үг та нарт хамгаас хэцүү санагддаг. Иймээс та нар хэтэрхий багыг ойлгож, Надаар үг нэг бүрээ тайлбарлуулах шаардлагатай байдаг тул Би улам ихийг айлддаг. Гэхдээ хэтэрхий их санаа зовох хэрэггүй. Би та нарт Өөрийн ажлын дагуу ярих болно.

84-Р БҮЛЭГ

Хүмүүс Миний тухай мэдлэг дутмагаасаа үүдэн Миний удирдлагад саад болж, Миний төлөвлөгөөг тоо томшгүй удаа сүйтгэсэн боловч урагшлах алхааг минь саатуулж хэзээ ч чадаагүй. Учир нь Би бол мэргэн ухааны Бурхан билээ. Надад энгүй мэргэн ухаан бий, мөн зах хязгааргүй, ой тойнд багташгүй нууц бий. Балар эрт цагаас эхлээд хүмүүс үүнийг ухан мэдэж, бүрэн ойлгож хэзээ ч чадаагүй. Тийм биз дээ? Миний айлддаг үг бүрд мэргэн ухаан байдгаар үл барам, бас үг болгон Миний далд нууцыг агуулдаг. Миний дотор бүгд нууц; Би бүх талаараа нууц. Та нар өнөөдөр ердөө нууцыг харсан, өөрөөр хэлбэл, Миний үнэн биеийг харсан—гэхдээ дотор нь нуугдсан энэхүү нууцыг хараахан тайлаагүй. Хүмүүс Миний удирдлагыг дагаж байж л Миний хаанчлалд орж чадна; эс бөгөөс тэд дэлхий ертөнцтэй хамт

сөнөж, үнс чандруу болно. Би бол бүрэн төгс Бурхан Өөрөө; Бурханаас Өөрөөс нь өөр хэн ч биш. “Бурханы илрэл” гэх зэрэг урьдын үгс аль хэдийн хоцрогдсон; тэдгээр нь цаашид хэрэглэгдэхгүй, үеэ өнгөрөөж, хуучирсан зүйлс юм. Та нараас хэд чинь үүнийг ойлгож авсан бэ? Та нараас хэд чинь энэ хэмжээнд хүртэл Миний талаар итгэлтэй байсан бэ? Би бүхнийг тодорхой тайлбарлаж, зааварчлах ёстой.

Сатаны хаанчлал устгагдсан бөгөөд Сатаны хүмүүс удахгүй Надад үйлчлэлээ үзүүлж дуусгана. Тэд Миний гэрээс нэг нэгээрээ хөөгдөнө, өөрөөр хэлбэл, урьд нь янз бүрийн дүр эсгэж явсан хүмүүсийн үнэн төрх өнөөдөр илчлэгдэж, бүгд Миний хаанчлалаас таслагдана. Бүү март! Өнөөдрөөс эхлэн, урьд нь хаягдсан хүмүүсийг оролцуулаад Миний хаядаг бүх хүн бол ердөө л дүр эсгэж байгаа, хуурамч амьтад юм; тэд Надад ердөө жүжиг тавьж байсан ба энэ жүжиг дуусмагц тэд тайзыг орхих ёстой. Үнэхээр Миний хөвгүүд болох хүмүүс Миний хайрыг хүртэж, та нарт зориулж аль хэдийн бэлдсэн ерөөлийг минь эдлэхээр Миний хаанчлалд албан ёсоор багтана. Ууган хөвгүүд ерөөлтэй еэ! Та нар Миний сургалтыг урьдчилан хүлээн авсан учраас одоо Надад ашиглуулахад тохирдог. Төгс хүчит Бурхан мөн гэдэгт минь итгэ. Хүмүүсийн биелүүлж чадахгүй зүйлийг Би саадгүй хийж чадна, үүнтэй өрсөлдөх боломж гэж ер үгүй. Өөрсдийгөө юу ч хийж чадахгүй, Миний ууган хөвгүүд байхад тэнцэхгүй гэж бүү бодоцгоо. Та нар бүрэн тохирно! Яагаад гэвэл, бүх зүйл Надад түшиглэн хийгддэг; Надад түшиглэн бүгд гүйцэлддэг. Яагаад та нар одоо өөрсдийгөө ийм биеийн хэмжээтэй байна гэж боддог вэ? Ердөө л та нарыг үнэхээр ашиглах цаг минь хараахан болоогүйгээс тэр юм. Агуу авьяасыг шалихгүй зорилгод ашиглаж болохгүй; ойлгов уу? Бүх орчлон ертөнц дээр та нар жижигхэн Хятадаар л хязгаарлана гэж үү? Өөрөөр хэлбэл, та нар ууган хөвгүүд бөгөөд ахан дүүсээ удирдах нь та нарын гүйцэтгэх учиртай үүрэг тул бүхий л орчлон ертөнц дэх бүх хүнийг хариул, залж чиглүүл хэмээн та нарт өгнө. Үүнийг мэдэж ав! Би бол төгс хүчит Бурхан! Би та нарт жаргах боломж олгож байгаагаа дахин нэг онцолъё. Би бол ажиллаж байгаа Нэгэн—Ариун Сүнс хаа сайгүй ажиллаж, биечлэн удирдаж байна.

Урьд нь хүмүүс Миний авралын талаар ямар ч ойлголтгүй байсан. Та нар одоо ойлгож байна уу? Миний аврал хэд хэдэн тал бий: Нэг нь гэвэл, зарим хүнийг огт урьдчилан тогтоогоогүй байдаг, өөрөөр хэлбэл, тэд Миний нигүүлслийг огт эдэлж чадахгүй; нөгөө нь гэвэл, анх урьдчилан тогтоогдсон, Миний нигүүлслийг хэсэг зуур эдэлдэг хүмүүс байдаг ч Өөрийнхөө урьдчилан тодорхойлсон хугацааны дараа Би тэднийг таягдан хаяж, тэдний амь бүрмөсөн дуусна. Өөр нэг тал нь, Миний урьдчилан тогтоож, сонгосон, мөнхийн ерөөл эдэлдэг хүмүүс байдаг; тэд Намайг хүлээн авахынхаа өмнө болон дараа туулсан зовлон бэрхшээл, Намайг хүлээн авсныхаа дараа хүртсэн гэгээрэл, гэрэлтүүлэлтийг оролцуулаад Миний нигүүлслийг эхнээс нь дуустал эдэлдэг. Одоогоос эхлэн тэд ерөөл эдэлж эхэлнэ—өөрөөр хэлбэл, тэд бол Миний бүрэн гүйцэд аварч буй хүмүүс юм. Энэ бол Миний агуу ажлын биелэлтийн хамгийн тодорхой илэрхийлэл билээ. Тэгвэл ерөөл гэж юуг хэлдэг вэ? Би та нараас асууя: Та нар юуг хамгийн их хийхийг хүсдэг вэ? Юуг

хамгийн их үзэн яддаг вэ? Юу олж авна гэж хамгийн их найддаг вэ? Та нар Намайг олж авч, амиа өсгөхийн төлөө л өнгөрсөн хугацаанд зовлон, бэрхшээл туулсан; эдгээр нь нигүүлслийн нэг хэсгийг бүрдүүлдэг. “Ерөөл” гэдэг нь ирээдүйд та нар үзэн яддаг зүйлгүй болно гэсэн үг, өөрөөр хэлбэл, эдгээр зүйл бодит амьдралд чинь байхаа болино; нүдэн дээр чинь тэдгээр нь бүрмөсөн арилсан байх болно. Гэр бүл, ажил, эхнэр, нөхөр, үр хүүхдүүд, найз нөхөд, төрөл төрөгсөд, мөн өдөр бүр үзэн яддаг өдрийн гурван удаагийн хоол чинь ч үгүй болно. (Энэ нь цаг хугацаагаар хязгаарлагдалгүй, махбодоосоо бүрэн алхан гарах гэсэн үг юм. Цадсан сүнс чинь л биеийг чинь хэвээр хадгалж чадна, гэхдээ энэ нь махбодыг бус, биеийг чинь хэлж байна. Та нар бүрэн чөлөөтэй, ер бусын байх болно. Энэ бол дэлхий ертөнцийг бүтээснээс хойш Бурханы үзүүлсэн хамгийн агуу, хамгаас илэрхий гайхамшиг юм.) Хөрс шорооны бүх бүрэлдэхүүн хэсэг биеэс чинь арилж, та нар ариун, хир буртаггүй, тэр чигтээ сүнслэг биес болж, орчлон ертөнц даяар, мөн газар дэлхийн зах хязгаар хүртэл аялж чадна. Тэр цагаас эхлээд та нар яршигтай тэр бүх угаалга, цэвэрлэгээнээс ч бас ангижирч, ердөө тултлаа жаргах болно. Тэр цагаас эхлэн, та нар гэрлэлтийн талаар бодохоо болино (учир нь, Би дэлхий ертөнцийг бүтээж буй бус, эрин үеийг төгсгөж байгаа), эмэгтэйчүүдэд хамгийн шаналгаатай байдаг төрөхийн өвдөлт гэж байхаа болино. Та нар ирээдүйд ажиллах ч үгүй, хөдөлмөрлөх ч үгүй. Та нар өөрсдийгөө Миний хайрын тэврэлтэд бүрэн умбуулж, өөрсдөд чинь өгсөн Миний ерөөлийг эдэлнэ. Ингэх нь гарцаагүй. Энэ ерөөлийг эдэлж байх зуур чинь нигүүлсэл та нарыг үргэлжлүүлэн дагана. Та нарт зориулж Миний бэлдсэн бүхэн буюу дэлхий дахины ховор, нандин эрдэнэсийг та нарт өгнө. Яг одоо та нар энэ бүхнийг ойлгож ч, төсөөлж ч чадахгүй бөгөөд урьд нь нэг ч хүн тэдгээрийг эдлээгүй. Энэ ерөөл өөрсөд дээр чинь ирэхэд та нар эцэс төгсгөлгүй туйлаас баярлах боловч эдгээр нь Миний хүч чадал, Миний үйлдэл, Миний зөвт байдал, үүнээс ч илүүтэйгээр Миний сүр жавхлангаас үүддэг гэдгийг бүү март. (Би нигүүлсэнгүй байхаар сонгосон хүмүүстээ нигүүлсэнгүй хандаж, өршөөнгүй хандахаар сонгосон хүмүүстээ өршөөнгүй хандана.) Тэр үед, та нарт эцэг эх гэж байхгүй, цусан төрөл гэж байхгүй байх болно. Та нар бол Миний хайрладаг бүх хүн, Миний хайртай хөвгүүд билээ. Тэр цагаас хойш та нарыг хэн ч дарлаж зүрхлэхгүй. Энэ нь та нарын өсөж том болох цаг, түүнчлэн улс үндэстнүүдийг төмөр саваагаар захирах цаг чинь байх болно! Миний хайртай хөвгүүдэд хэн саад болж зүрхлэх билээ? Миний хайртай хөвгүүд рүү хэн дайрч зүрхлэх билээ? Эцэг нь алдрыг олж авсан тул бүгд Миний хайртай хөвгүүдийг хүндэлнэ. Хэний ч, хэзээ ч төсөөлж байгаагүй бүх зүйл нүдний чинь өмнө гарч ирнэ; тэдгээр нь хязгааргүй, шавхагдашгүй, эцэс төгсгөлгүй байх болно. Төд удалгүй та нар, наранд түлэгдэж, төөнөсөн халууныг тэсвэрлэх шаардлагагүй болох нь лавтай, мөн та нар жихүүн хүйтнийг туулахгүй, бороо, цас, салхи ч та нарт хүрэхгүй. Учир нь Би та нарыг хайрладаг бөгөөд энэ нь тэр чигтээ Миний хайрын ертөнц байх болно. Би та нарт хүссэн бүхнийг чинь өгч, хэрэгтэй бүхнийг чинь бэлдэнэ. Намайг зөвт биш гэж хэлж

зүрхлэх хэн байна? Миний уур хилэн (ёрын муу хүмүүсийн эсрэг) мөнхөд үргэлжилнэ гэдгийг Би урьд нь хэлсэн учраас жаахан ч гэсэн зөөлөн хандалгүйгээр чамайг тэр даруй хөнөөнө. Гэвч, Миний хайр ч бас (Өөрийн хайрт хөвгүүдийг гэсэн) мөнхөд үргэлжилнэ; үүнийгээ Би өчүүхэн ч хорихгүй.

Өнөөдөр Миний үгийг шүүлт хэмээн сонсдог хүмүүс бол зөв байр байдалгүй хүмүүс юм. Гэхдээ тэд үүнийг олж мэдэх цагт Ариун Сүнс өөрсдийг нь аль хэдийн орхичихсон байх болно. Бүхий л орчлон ертөнцөд та нарын дундаас ууган хөвгүүдийг сонгосон боловч хөвгүүд болон ардууд та нарын багахан хэсгийг л эзэлдэг. Би бүхий л орчлон ертөнцийг онцолж байгаа нь хөвгүүд болон ардуудыг дэлхийн бүх улс үндэстнээс сонгодог гэсэн үг юм. Ойлгов уу? Ууган хөвгүүд хурдан өсөж, харийнхныг удирдахаар явах хэрэгтэй гэж Би яагаад онцолсоор байдаг вэ? Та нар Миний үгийн жинхэнэ утгыг ойлгож байна уу? Яагаад гэвэл, Хятад бол Миний хараасан үндэстэн; энэ нь Намайг хамгийн их хяхан хавчсан, Би Хятадыг хамгийн их үзэн яддаг. Би болон Миний ууган хөвгүүд тэнгэрээс ирсэн, бүх орчлон ертөнцийн хүмүүс гэдгийг чи мэдэх ёстой; бид аль нэг улс үндэстэнд харьяалагддаггүй. Хүний үзэлтэй зууралдахаа боль! Учир нь Би та нарт Өөрийн үнэн биеийг илчилсэн. Бүх зүйл Надаас шалтгаалдаг. Та нар Миний үгийг санаж чадах уу? Та нарын дунд улам цөөн хүн байгаа ба хүн ам улам бүр цэвэршжээ гэж Би яагаад хэлдэг вэ? Учир нь Миний аврал аажмаар орчлон ертөнц рүү хандаж байна. Таягдан хаягддаг, Миний нэрийг хүлээн авсан хүмүүс бол ууган хөвгүүдийг төгс болгохын төлөө үйлчлэл үзүүлсэн хүмүүс юм. Ойлгов уу? Тэд бүгд Миний хөвгүүдэд үйлчлэл үзүүлсэн хүмүүс гэж Би яагаад хэлдэг вэ? Одоо та нар үнэхээр ойлгосон, тийм биз дээ? Тоо хэмжээ нь үнэхээр хомс; яах аргагүй цөөхөн байна. Гэвч тэр хүмүүс Миний хөвгүүдээс болоод нэлээд их ашиг тус хүртэж, Миний нигүүлслээс ихийг эдэлсэн, тийм учраас Би хүн төрөлхтнийг эцсийн удаа аварч байна гэж хэлсэн юм. Одоо та нар Миний үгийн жинхэнэ утга учрыг мэдлээ! Намайг эсэргүүцдэг хэнийг ч Би хатуу гэсгээж, Намайг хамгаалдаг хэнд ч Өөрийн царайг хандуулна. Яагаад гэвэл, бүр анхнаасаа л Би үргэлж сүр жавхлант, зөвт Бурхан байсан бөгөөд бүх зүйл та нарт илчлэгдэнэ. Би гайхалтай арга замаар түргэн шалмаг ажилладаг ба хүмүүсийн төсөөлж чадашгүй гайхалтай зүйлс удахгүй тохиолдоно. Би үнэхээр нэн даруй, удахгүй гэж хэлж байна. Та нар ойлгож байна уу? Амийн оролтыг алгуурлалгүй эрж хай! Миний хайртай хөвгүүд ээ, энд бүх зүйл та нарын төлөө байдаг, бүх зүйл та нарын төлөө оршин тогтнодог.

85-Р БҮЛЭГ

Би Өөрийн хүслийг биелүүлэхийн тулд өөр өөр хүмүүсийг ашигладаг: Миний гэсгээдэг хүмүүст Миний хараал биелдгийн адил Миний хайрладаг хүмүүст Миний ерөөл биелдэг. Одоо та нарын дундаас хэн Миний ерөөлийг хүртэж, хэн Миний

хараалыг эдлэх нь Миний ганцхан үгээс шалтгаалдаг, бүгд Миний айлдвараар тодорхойлогддог. Одоо Миний сайн ханддаг хүн бүр Миний ерөөлийг үргэлж хүртэх нь лавтай (өөрөө хэлбэл, Намайг аажмаар мэдэж авч, Надад улам бат итгэдэг болж, шинэ гэрэл, илчлэл олж авч, Миний ажлын хэмнэлтэй хөл нийлүүлж чаддаг байна) гэдгийг чи мэднэ. Миний жигшдэг хэн ч бай (энэ бол хүмүүс гаднаас нь харж чадахгүй, Миний дотроо хадгалдаг зүйл) Миний хараалыг заавал эдэлнэ, тэд агуу улаан лууны үр удмын нэг эргэлзээгүй мөн тул түүнийг хараасан Миний хараалаас хувь хүртэнэ. Миний харж тэвчдэггүй, хэв чанар нь дутагдалтай гэж Би боддог, Надаар төгс болгуулж, ашиглуулж чадахгүй хүмүүсийн тухайд гэвэл тэдэнд одоо ч аврагдах боломж бий бөгөөд тэд Миний хөвгүүдийн нэг байх болно. Хэрэв хүнд Миний хэв чанарын аль нь ч байхгүй, сүнслэг хэрэг явдлыг ухаарч ойлгодоггүй, Намайг мэддэггүй боловч оргилуун сэтгэлгээтэй бол Миний ардуудын нэгээр томилогдох болно. Миний хараал хүрсэн хүмүүсийг Би аврагдах аргагүй гэж тооцдог бөгөөд тэд бол муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн хүмүүс юм. Би тэднийг хөөж явуулахын хүслэн болж байна. Тэд агуу улаан луунаас төрсөн ба Би тэднийг хамгаас их үзэн яддаг. Энэ мөчөөс эхлэн, Надад тэднээр үйлчлэл хийлгэх хэрэг үгүй. Тэд зүгээр л Надад цаашид хэрэггүй! Тэдний хэн нь ч хэрэггүй! Тэд Миний өмнө уйлж, шүдээ хавирсан ч ямар ч үр дүнгүй, Би тэдний хэн рүү нь ч харалгүй, зүгээр л өшиглөн явуулдаг. Чи юу юм бэ? Чи Миний өмнө байх зохистой юу? Чи үнэ цэнтэй юу? Чи сайн хүн царайлж, даруу төлөв дүр эсгэсээр л байна! Тэр их олон муу зүйлийг хийсний чинь дараа чамайг Би өршөөж чадна гэж үү? Тэгээд бас чи Миний өмнө өргөгдөнгүүтээ л Намайг дахиад үл ойшоож эхэлдэг. Чамд хэзээ ч сайн санаа зорилго байгаагүй, чи ердөө л Намайг мэхлэх гэдэг! Агуу улаан лууны удам байж чи үнэхээр сайн хүн болж чадах уу? Тэр бүтэшгүй! Би чамайг аль эрт хараасан бөгөөд нэгд нэгэнгүй шүүдэг! Надад бүхий л зүрх сэтгэлээрээ, үнэнчээр, сахилга баттайгаар үйлчлэл үзүүл, дараа нь ёроолгүй нүх рүүгээ буцаад яв! Чи Миний хаанчлалаас хувь хүртэх гэв үү? Битгий мөрөөд! Ичгүүргүй юм! Бохир заваан биетэй, тодорхой хэмжээгээр завхарсан байж чамд бас Миний өмнө зогсох зориг зүрх байна гэнэ ээ! Замаас зайл! Хэрэв чи ахиад алгуурлавал, Би чамайг хатуу шийтгэнэ! Миний өмнө шударга бус зан гаргаж, заль мэх хэрэглэдэг бүх хүн илчлэгдэх ёстой. Чи хаана нуугдаж чадах вэ? Хаана өөрийгөө далдалж чадах вэ? Хэчнээн булташ, нуугдлаа гэсэн чи Миний хяналтаас зайлж чадна гэж үү? Хэрэв чи Надад зохих ёсоор үйлчлэл хийхгүй юм бол амь нас чинь улам богиносох болно; чи тэр даруйдаа дуусах болно!

Миний ууган хөвгүүд гэж ямар хүмүүс байдгийг Би та нарт тов тодорхой хэлж, яг таг баталж харуулъя. Тэгэхгүй бол та нар зохих байраа эзэлж чадахгүй, харин ч байр суурь чинь ямар байх учиртайг хамаа замбараагүй шийдэх болно. Зарим нь хэтэрхий даруу, зарим нь хэтэрхий цадиггүй байна; Миний хэв чанарыг эзэмшдэггүй, эсвэл өөрсдийнх нь хэв чанар дэндүү дутмаг хүмүүс бүгд Миний ууган хөвгүүд байхыг хүснэ. Миний ууган хөвгүүдээс ямар илэрхийлэл гардаг вэ? Юуны

түрүүнд, тэд Миний хүслийг ухаарахад анхаарлаа төвлөрүүлж, Миний хүслийг хайхардаг, үүний зэрэгцээ Ариун Сүнс тэд бүгд дээр ажилладаг. Хоёрдугаарт, тэд сүнс дотроо уйгагүй эрж хайж, эх захаа алдалгүй, үргэлж Миний хил хязгаар дотор байдаг, туйлын хэвийн хүмүүс юм. Түүнчлэн эдгээр зан авир нь дуураймал биш (учир нь тэд ариун Сүнсний ажлыг мэдрэхэд төвлөрч, өөрсдийг нь гэх Миний хайрыг хайхарч, цаг үргэлжид сэрэмжтэй байдаг ба Надаас урвадаг, Намайг үл ойшоодог сэтгэлгээтэй болохоос гүнээ эмээдэг). Гуравдугаарт, тэд үнэн сэтгэлээсээ Миний төлөө үйлддэг, өөрсдийгөө бүхэлд нь зориулах чадвартай бөгөөд өөрсдийн хэтийн ирээдүй, амьдрал, юу идэж, өмсөж, эдлэх, эсвэл хаана амьдрах тухай аль хэдийн бодохоо больсон байдаг; Дөрөвдүгээрт, тэд ямагт зөв шударга байдлын төлөө өлсөж, цангадаг бөгөөд өөрсдийгөө ихэд дутагдалтай, биеийн хэмжээ нь хэтэрхий дутуу дулимаг гэж боддог; Тавдугаарт, Миний түрүүнд дурдсанчлан, тэд дэлхий дээр нэр хүнд сайтай боловч дэлхийн хүмүүст хөсөр хаягдсан юм. Тэд эсрэг хүйстэнтэйгээ харилцахдаа ёс зүйтэй байдаг. Энэ бүгд баталгаа боловч Миний ажил тэр үе шатанд хараахан хүрээгүй байгаа учраас эдгээрийг би одоо та нарт бүрэн илчилж чадахгүй нь. Ууган хөвгүүд ээ, санаж яв! Чиний доторх амийн мэдрэмж, Намайг гэх хүндлэл, хайр, Миний тухай мэдлэг, Намайг гэсэн эрэл хайгуул, та нарын итгэл—энэ бүх зүйл та нарыг гэх Миний хайрын биелэл, та нарт өгөх Миний баталгаа юм, ингэснээр та нар үнэхээр Миний хайртай хөвгүүд болж, Надтай адил байж, хосгүй алдар сууг мандуулан Надтай цуг идэж, хамт амьдарч, ерөөл эдлэх боломжтой билээ.

Өнгөрсөн хугацаанд Намайг хавчсан, Намайг огт мэддэггүй байсан (Миний нэр гэрчлэгдэхээс өмнөх үед ч гэсэн), Намайг хүн гэж итгэсэн болон Намайг доромжилж, гүжирдсэн хэнд ч болов Би ямар ч өршөөл үзүүлж чадахгүй. Тэд яг одоо Надад хамгаас цангинасан гэрчлэл хийлээ ч нэмэргүй. Намайг урьд нь хяхаж хавчсанаараа тэд Надад үйлчлэл хийж байсан бөгөөд өнөөдөр Надад гэрчлэл хийсэн ч гэсэн Миний хэрэгсэл хэвээр л үлдэх болно. Би зөвт Бурхан Өөрөө агаад махбодоос гарч, Өөрийгөө газрын бүх харилцаанаас тасалсан учир өнөөдөр Надаар үнэхээр төгс болгуулсан хүмүүс л Надад хэрэгтэй. Би бол Бурхан Өөрөө, өнгөрсөн үед Миний эргэн тойронд байсан бүх хүн, хэрэг явдал, эд зүйл Миний гарт бий. Надад сэтгэл хөдлөл гэж үгүй бөгөөд бүх зүйлд зөвт байдлыг хэрэгжүүлдэг. Би бол өчүүхэн төдий ч хир буртгаар бохирдоогүй шулуун шударга. Миний үгийн утга учрыг ойлгов уу? Та нар бас үүнд хүрч чадах уу? Хүмүүс Намайг бас хэвийн хүн чанартай, гэр бүлтэй, сэтгэл хөдлөлтэй гэж боддог ч, энэ чинь шал буруу гэдгийг та нар мэдэж байна уу? Би бол Бурхан! Та нар үүнийг мартчихсан уу? Будилчихсан уу? Та нар одоо ч Намайг мэддэггүй!

Миний зөвт байдал та нарт бүрэн илчлэгдсэн. Би ямар ч хүнтэй яаж ч харьцлаа гэсэн Миний зөвт байдал, Миний сүр жавхлан ил болдог. Би бол уур хилэнг бас Өөртөө тээж явдаг Бурхан Өөрөө учир Намайг хавчиж, эсвэл доромжилсон нэг ч хүнийг зүгээр өнгөрөөхгүй. Ийм хатуу чанд шаардлага дор та нар үүнийг тодорхой

ойлгож байна уу? Миний сонгож, урьдчилан тогтоосон хүмүүс бол ховор сувд, гартаам мэт олдоход бэрх. Учир нь хаан болж хаанчлах хүмүүс Миний ардууд байх хүмүүсээс хамаагүй цөөн байх нь тодорхой бөгөөд энэ нь Миний хүч чадал, гайхамшигт үйл хэргийн илрэл билээ. Би та нарыг шагнаж, та нарт титэм зүүлгэнэ, Надтай хамт байгаа үед алдар суу хэзээ ч дуусахгүй гэж Би үргэлж хэлдэг. Шагнал, титэм, алдар суу гэдгээр Би юуг хэлж байна вэ? Хүмүүсийн үзэлд шагнал гэдэг хоол, хувцас, эдлэл хэрэглэл шиг биет зүйл, гэвч энэ бол бүхэлдээ хуучинсаг үзэл бодол; Би ингэж хэлэх гээгүй, энэ нь алдаатай ойлголт юм. Шагнал гэдэг бол яг одоо олж авдаг зүйлс бөгөөд нигүүлслийн нэг хэсэг юм. Гэхдээ махан биеийн таашаалтай холбоотой зарим нэг шагнал ч бас байдаг бөгөөд Надад үйлчлэл үзүүлдэг боловч Миний аврахгүй хүмүүс бас зарим нэг материаллаг тааламжийг хүртэж болно (тэгсэн ч тэд Надад үйлчлэл хийдэг биет зүйл хэвээр байдаг). Титэм бол албан тушаалын сүлд тэмдэг биш юм. Өөрөөр хэлбэл, энэ нь та нарыг баясгах гэж өгдөг биет зүйл бус, харин та нарт Миний хайрладаг шинэ нэр бөгөөд шинэ нэрийнхээ энд хүрч чадсан хэн боловч титэм хүртэж, үүгээрээ Надаас ерөөл хүртдэг. Шагнал, титэм зэрэг нь ерөөлийн нэг хэсэг боловч ерөөлтэй харьцуулбал тэнгэр газар шиг ялгаатай юм. Алдар сууг чухамдаа хүмүүсийн үзлээр төсөөлөх боломжгүй, учир нь алдар суу гэдэг биет зүйл бус, харин хүмүүсийн туйлын хийсвэрээр сэтгэдэг зүйл юм. Тэгвэл алдар суу гэж юу вэ? Та нар Надтай цуг алдар суугаа мандуулан бууж ирэх болно гэж хэлдгийн учир утга юу вэ? Миний бүрэн бүтэн байдал, өөрөөр хэлбэл, Би юу болох, Надад юу байгаа, өршөөл, энэрэл (Өөрийн хөвгүүдийг гэх), зөвт байдал, сүр жавхлан, шүүлт, уур хилэн, хараал, шатаалт (бүх хүмүүсийг гэх) болох Миний үнэн бие бол алдар суу юм. Би Өөрт минь эцэс төгсгөлгүй алдар суу байдаг гэж хэлдгийн учир юу вэ? Яагаад гэвэл Надад эцэс төгсгөлгүй мэргэн ухаан төдийгүй зүйрлэшгүй арвин баялаг бий. Иймээс, Надтай хамт алдар суугаа мандуулан бууж ирнэ гэдэг нь та нар аль хэдийн Надаар бүрэн төгс болгуулсан, Миний юу болох, Надад юу байгааг олж авсан, Надаар төгөлдөржсөн, Намайг хүндэтгэдэг, Намайг эсэргүүцдэггүй гэсэн үг юм. Та нар одоо ойлгосон нь лавтай!

Газар дэлхийн бүх улс үндэстний хурцадмал байдал оргилдоо хүрсэн бөгөөд Надад үйлчлэл үзүүлж, Надаар үнс нурам болгуулахаар бүгд тасралтгүй бэлдэж байна. Миний уур хилэн, дүрэлзэх гал ирэхэд өмнө нь ямар ч сэжүүр гарахгүй. Гэвч Би Өөрийн хийж байгаа зүйлийг юу болохыг мэддэг бөгөөд надад маш тодорхой байдаг. Та нар Миний үгэнд бат итгэж, бүх бэлтгэлээ базаахаар яаравчлах хэрэгтэй. Хилийн чанадаас эрж хайж ирэх хүмүүсийг хариулахад бэлтгэлтэй бай. Үүнийг санаж яв! Хятад—өөрөөр хэлбэл, Хятад дахь хүн бүр, газар бүр—Миний хараалд өртөнө. Миний үгийн утга учрыг ойлгов уу?

86-Р БҮЛЭГ

Хүмүүс Намайг өршөөлт Бурхан гэцгээдэг; тэд Намайг Өөрийн бүтээсэн бүхэнд аврал авчирна гэдэг. Эдгээрийг бүгдийг нь хүний үзэлд тулгуурлан хэлсэн юм. Намайг өршөөлт Бурхан гэж Миний ууган хөвгүүдэд хэлсэн бөгөөд Намайг бүгдэд аврал авчирдаг гэж Миний хөвгүүд, Миний ардуудад хэлсэн. Би мэргэн ухаантай Бурхан учир ямар хүмүүсийг хайрладаг, ямар хүмүүсийг үзэн яддаг болох нь Миний оюун ухаанд тодорхой байдаг. Би Өөрийн хайрладаг хүмүүсийг эцсээ хүртэл үргэлж хайрлах бөгөөд энэ хайр хэзээ ч хувирахгүй. Харин Миний үзэн яддаг хүмүүс хэчнээн сайхан авирлалаа ч Миний сэтгэл өчүүхэн ч хөдлөхгүй. Учир нь тэд Надаас төрөөгүй, Миний хэв чанар, Миний амийг эзэмшдэггүй. Өөрөөр хэлбэл, Би эндүүршгүй учир тэднийг урьдчилан тогтоож, сонгоогүй. Тэгэхээр Миний бүх үйл хэрэг ариун бөгөөд хүндтэй гэж нэрлэгддэг, Надад харамсах зүйл хэзээ ч байдаггүй. Хүмүүсийн нүдээр бол Би туйлын хатуу сэтгэлтэй—гэвч чи Намайг зөвт, сүр жавхлант Бурхан Өөрөө гэдгийг танихгүй байна гэж үү? Миний юм бүхэн зөв; Миний үзэн яддаг хүмүүс Миний хараалыг заавал хүртэнэ, Миний хайрладаг хүмүүс Миний ерөөлийг заавал хүртэнэ. Энэ бол Миний ариун, халдашгүй зан чанар агаад хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Энэ бол гарцаагүй!

Миний ажил шулуун шударга, нарийн нягт агаад юуг ч дутуу орхидоггүй тул өнөөдөр Миний санаа зорилготой үнэхээр нийцдэг хүмүүсийг Би заавал бүрэн төгс болно. Миний хараасан хүмүүс шатаагдах болно. Тэгвэл хүмүүсийн дийлэнх нь Надад хараагдсан атал Ариун Сүнс яагаад тэдэн дээр ажилласан хэвээр байна вэ (Би бузар сүмд оршин байдаггүйтэй холбон үүнийг хэлдэг)? Бүх хэрэг явдал, бүх зүйл Христэд үйлчлэл үзүүлдэг гэж хэлдгийн цаад жинхэнэ утгыг та нар ойлгодог уу? Би тэдний үйлчлэлийг ашиглахад Ариун Сүнс тэднээр дамжуулж Өөрийн ажлыг хийдэг, гэвч ердийн үед тэд Надад үйлчлээгүй байх үедээ үндсэндээ сүнсээрээ гэгээрээгүй байдаг. Тэд үнэхээр эрж хайлаа ч гэсэн, тэр нь урам зоригоос үүдэлтэй бөгөөд Сатаны заль мэх юм—учир нь жирийн үед тэд Миний ажилд огт анхаарал хандуулдаггүй, мөн Миний ачааг огтоос хайхардаггүй. Одоо Миний ууган хөвгүүд өсөж том болсон учир, Би тэднийг өшиглөн явуулдаг; энэ шалтгааны улмаас Миний Сүнс хаа сайгүй буцаж, Миний ууган хөвгүүд дээр онцгой анхаарал очсон. Чи ойлгов уу? Бүх зүйл Миний үйл хэрэг, урьдчилан тогтоолт, Миний амнаас гарах үгээс шалтгаалдаг. Миний ерөөлийг хүртсэн бүх газар бол заавал Миний ажилладаг, Миний ажил хэрэгждэг газар байна. Хятад бол Сатаныг хамгийн их шүтдэг үндэстэн тул Би үүнийг хараасан. Түүнчлэн энэ бол Намайг хамгийн их хавчсан үндэстэн юм. Би агуу улаан лууны нөлөөнд байгаа хүмүүст Өөрийн ажлыг яасан ч хийхгүй. Миний үгийн жинхэнэ утга учрыг ойлгов уу? Эцсийн эцэст, Миний хөвгүүд, Миний ардууд цөөхөн. Гарцаагүй бүх зүйл Миний гарт бий; Миний сонгож, урьдчилан тогтоосон хүмүүст эрч хүчийг төвлөрүүлж, илүү их хүчин чармайлт зарцуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Миний ууган хөвгүүд Миний ачааг аль болох

хурдан хуваалцахын тулд яаран хэрэгжүүлж, Миний ажилд бүх хүчин чармайлтаа зориулах хэрэгтэй.

Надад үйлчлэл хийдэг хүмүүс ээ, сонсоцгоо! Та нар Надад үйлчлэл хийж байхдаа Миний нигүүлслээс хүртэж болно. Өөрөөр хэлбэл, та нар Миний хожмын ажлын тухай, хойшид болох зүйлсийн тухай түр хугацаанд мэдэх боловч үүнийг огтхон ч эдлэхгүй. Энэ бол Миний нигүүлсэл юм. Чиний үйлчлэл дуусах үед хоргодоод байлгүй тэр даруй яв. Миний ууган хөвгүүд болсон хүмүүс биеэ тоосон байх ёсгүй боловч бардам байхыг зөвшөөрнө, учир нь Би та нарт эцэс төгсгөлгүй ерөөл хайрласан билээ. Сүйрлийн бай болсон хүмүүс өөрсдөдөө гай авчирч, эсвэл хувь заяандаа гуниад хэрэггүй. Чи Сатаны үр удам биш гэж үү? Чи Надад үйлчлэл хийж дууссаныхаа дараа ёроолгүй нүх рүү буцан очиж магадгүй, учир нь чи Надад цаашид ямар ч хэрэггүй болно. Тэгээд Би та нарт Өөрийн гэсгээлтээр хандаж эхэлнэ. Би ажиллаж эхэлсэн л эцсийг нь үзнэ; Миний үйл хэрэг гүйцэлдэнэ, Миний гүйцэтгэсэн зүйл үүрд оршин тогтноно. Энэ бүгд нь Миний ууган хөвгүүд, Миний хөвгүүд, Миний ардуудад хамаатай, бас та нарт ч хамаатай; та нарыг гэсгээх Миний гэсгээлт үүрд мөнх байна. Намайг эсэргүүцдэг хорон муу хүмүүсийг Би гарцаагүй гэсгээх болно гэдгээ та нарт өмнө нь олон удаа хэлсэн. Хэрэв чи Намайг эсэргүүцсэнийхээ дараа Ариун Сүнсэнд зэмлүүлээгүй бол аль хэдийн хараагдсан хэрэг бөгөөд дараа нь Миний гарт цохиулж унах болно. Хэрэв чи Миний тухай муу муухайг бодох үедээ Ариун Сүнсээр сахилгажуулагддаг бол Миний ерөөлийг хүртсэн хэрэг; гэвч чи үргэлж сэрэмжтэй байж, хайхрамж, болгоомжоо хэзээ ч бүү алд.

87-Р БҮЛЭГ

Та нар алхаагаа түргэсгэж, Миний хийлгэхийг хүссэн зүйлийг хийх ёстой—Миний машид ирмүүн сэтгэлээр та нарт зориулах зүйл энэ билээ. Та нар одоо ч гэсэн Миний үгийн утга учрыг ойлгоогүй л байгаа юм биш биз? Миний санаа зорилгыг мэдэхгүй л байгаа юм биш биз? Би улам бүр тодорхой ярьж, улам ихийг хэлсэн боловч та нар Миний үгийн утга учрыг ухаарч ойлгох гэж хичээл зүтгэл гаргаагүй л байна уу? Сатан аа, Миний төлөвлөгөөг сүйтгэж чадна гэж бүү сана! Сатанд үйлчлэл хийдэг, өөрөөр хэлбэл Сатаны үр удам болсон хүмүүс (Сатанд эзэмдүүлсэн учраас гарцаагүй Сатаны амьтай тул Сатаны үр сад гэгддэг хүмүүст энэ хамаатай) Миний хөлд өршөөл гуйн, уйлж, шүдээ хавирдаг. Харин Би тийм тэнэг зүйл хийхгүй! Би Сатаныг уучилж чадна гэж үү? Би Сатанд аврал авчирч чадна гэж үү? Тэр боломжгүй! Би хэлснээ хийдэг бөгөөд үүндээ хэзээ ч харамсахгүй!

Би юу ч хэлсэн биелдэг. Тийм биш гэж үү? Гэсэн ч, та нар Надад итгэхгүй хэвээр, Миний үгэнд эргэлзэж, Намайг зүгээр л өөрсөдтэй чинь тоглож байна гэж боддог. Энэ бол ердөө л маш хөгийн юм. Би бол Бурхан Өөрөө! Ойлгов уу? Би бол Бурхан Өөрөө! Хэрэв Надад мэргэн ухаан, хүч чадал гэж үгүй байсан бол

хүссэнээрээ хэлж, хийж чадна гэж үү? Гэсэн ч, та нар Надад итгэхгүй л байна. Эдгээрийг Би та нарт ахин дахин онцолж, удаа дараа хэлсэн. Та нарын дийлэнх чинь яагаад одоо ч итгэдэггүй юм бэ? Яагаад эргэлзээ тээсээр байна вэ? Яагаад та нар өөрсдийн үзэлтэй амь тэмцэн зууралдсаар байгаа юм бэ? Тэдгээр нь чамайг аварч чадах уу? Би хэлснээ хийдэг. Миний үгийг үнэн гэж үзэж, бүү эргэлз гэж Би та нарт хэдэнтээ хэлсэн. Та нар тэдгээрийг нухацтай авч үзсэн үү? Ганцаараа чи юу ч хийж чадахгүй хэр нь Миний хийдэг зүйлд итгэж чаддаггүй. Ийм хүнийг юу гэж хэлж болох вэ? Шулуухан хэлбэл, Би та нарыг хэзээ ч бүтээгээгүй мэт л байна. Өөрөөр хэлбэл, чи Надад үйлчлэл үзүүлэгч байхад бүх талаараа тэнцэхгүй. Хүн бүр Миний үгэнд итгэх ёстой! Бүгд шалгалтыг давах ёстой; Би нэг ч хүнийг мултрахыг зөвшөөрөхгүй. Мэдээж, итгэдэг хүмүүс үүнд хамаагүй. Миний үгэнд итгэдэг хүмүүс Миний ерөөлийг гарцаагүй хүртэнэ, үүнийг итгэдэг зүйлийн чинь дагуу чамд өгч, чиний дотор биелнэ. Миний ууган хөвгүүд ээ! Одоо Би та нарт Өөрийн бүх ерөөлийг өгч эхэллээ. Та нар гэрлэлт, гэр бүл, хоол хүнс, хувцас хунар, нойр, мөн байгалийн бүх гамшиг (салхи, нар, бороо, хахир хавсарга, цас зудны гачлан, та нарын үзэн яддаг бусад бүх зүйл) зэрэг тэр бүх махан биеийн жигшүүрт хүлээсийг бага багаар хаяж эхэлнэ. Та нар орон зай, цаг хугацаа, газар зүйн хязгаарлалтад баригдалгүй далай тэнгис, хуурай газар дээгүүр, агаараар аялж, Миний хайрын тэврэлтэд үнэн голоосоо жаргаж, Миний хайр халамж дор бүхнийг хариуцах болно.

Миний бүрэн төгс болгосон ууган хөвгүүдээр бахархдаггүй хэн байна? Тэдний төлөө Миний нэрийг магтахгүй хэн байна? Яагаад Би одоо та нарт ийм олон нууц илчлэхийг хүснэ вэ? Яагаад өнгөрсөнд биш, одоо гэж? Энэ өөрөө нууц; чи үүнийг мэдэх үү? Өмнө нь Би яагаад Хятад бол Миний хараасан үндэстэн гэж дурдаагүй вэ? Надад үйлчлэл хийдэг хүмүүсийг Би яагаад ил болгоогүй вэ? Өнөөдөр Би та нарт үүнийг ч бас хэлье: Өнөөдөр, Миний бодлоор бүх зүйл гүйцэлдсэн бөгөөд Би Өөрийн ууган хөвгүүдтэй холбоотойгоор ингэж хэлж байна. (Учир нь өнөөдөр Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчлахаар ирсэн байна—тэгээд хэлбэрээ олсон төдийгүй Надтай хамт үнэхээр хаанчилж байна. Өнөөдөр дотор нь Ариун Сүнс ажилласан хүмүүс гарцаагүй Надтай хамт хаанчилдаг—үүнийг өчигдөр, маргааш бус, яг одоо илчилж байна.) Өнөөдөр Миний илчлэхийг хүсдэг хүмүүс илчлэгдсэн тул Өөрийн хэвийн хүн чанарын бүх нууцыг Би ил болгож байна, энэ бол Миний мэргэн ухаан. Миний ажил энэ алхам хүртэл ахилаа: Өөрөөр хэлбэл энэ мөчид Би, онцгойлон энэ цаг үед зориулан шийдсэн захиргааны зарлигийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ёстой. Ийм болохоор, Би ууган хөвгүүд, хөвгүүд, ардууд, үйлчлэл үзүүлэгчдэд зохих баталгааг олгож байгаа, учир нь Би эрх мэдэлтэй бөгөөд шүүлт хийж, төмөр саваагаар захирна. Надад дуулгавартайгаар үйлчлэл үзүүлэхгүй байж хэн зүрхэлдэг вэ? Хэн Надад гомдоллож зүрхэлдэг вэ? Намайг зөвт байдлын Бурхан биш гэж хэн хэлж зүрхлэх вэ? Та нарын чөтгөрлөг уг чанар аль эрт Миний өмнө илчлэгдсэн гэдгийг Би мэднэ: Миний сайн ханддаг хэнд ч

болов та нар атаархаж, үзэн яддаг. Энэ чинь гарцаагүй Сатаны уг чанар! Би Өөрийн хөвгүүдэд сайн ханддаг; чи Намайг зөвт биш гэж хэлж зүрхлэх үү? Би чамайг тэр чигт нь хөөгөөд явуулж чадна, гэвч азаар чи Надад үйлчлэл хийж байна, бас одоо цаг нь ч болоогүй байна; тийм биш сэн бол, Би чамайг хөөгөөд явуулах байсан юм!

Сатаны төрлийнхөн! Зэрлэг балмад байхаа больцгоо! Ярихаа боль! Үйлдэхээ боль! Миний ажлыг Миний сонгосон хөвгүүд, ардууд аль хэдийн гүйцэтгэж эхэлсэн бөгөөд аль хэдийн Хятадын гаднах бүх улс үндэстэн, бүх урсгал, нийгмийн бүх давхаргын хүмүүст түгж байна. Надад үйлчлэл үзүүлдэг хүмүүс яагаад үргэлж сүнсээрээ хаагдмал байдаг юм бэ? Яагаад тэд сүнслэг асуудлыг хэзээ ч ойлгодоггүй юм бэ? Яагаад Миний Сүнс энэ хүмүүс дээр огт ажиллахгүй байна вэ? Ерөнхийдөө, Би Өөрийн урьдчилан тогтоож, сонгоогүй хүмүүст хэтийдсэн их хүчин чармайлт зарцуулж ердөө чадахгүй. Миний урьдын зовлон шаналал, Миний уйгагүй халамж, хүчин чармайлт бүгд Миний ууган хөвгүүдийн төлөө, мөн хөвгүүд, ардуудын цөөхөн хэсгийн төлөө байж ирсэн; түүнчлэн хойшдын ажлаа саадгүй гүйцээж чадахын тулд, Өөрийн хүслийг саад тотгоргүй байлгахын тулд Би эдгээрийг хийсэн. Би ухаалаг Бурхан Өөрөө учир алхам бүрд зориулан зохих зохицуулалтыг хийсэн. Би ямар ч хүнийг авч үлдэх гэж чармайдаггүй (энэ нь сонгогдоогүй, урьдчилан тогтоогдоогүй хүмүүст чиглэдэг), ямар ч хүнийг хамаагүй цохиж унагадаггүй (энэ нь сонгогдсон, урьдчилан тогтоогдсон хүмүүст чиглэдэг): Энэ бол хэн ч өөрчилж болохгүй Миний захиргааны зарлиг! Би үзэн яддаг хүмүүстээ харгис байдаг; харин хайрладаг хүмүүсээ харж, хамгаалдаг. Иймээс Би хэлснээ хийдэг (Миний сонгодог хүмүүс сонгогдсон хүмүүс; Миний урьдчилан тогтоодог хүмүүс урьдчилан тогтоогдсон хүмүүс юм; эдгээр нь бүтээлээс өмнө Миний зохицуулсан үйл хэрэг билээ).

Миний зүрх сэтгэлийг хэн өөрчилж чадах вэ? Хүссэнээрээ зохиосон төлөвлөгөөнийхөө дагуу үйлдэж байгаа Надаас өөр, хэн хуумгай загнаж, Миний тушаалыг дагахгүй байж зүрхлэх вэ? Энэ бүгд нь Миний захиргааны зарлиг; тэдгээрээс ганцыг нь ч болов Надаас авч хэн зүрхлэх вэ? Бүх зүйл Миний тушаалаар байх ёстой. Тодорхой нэг хүн маш их зовсон, бас үнэнч, Миний зүрх сэтгэлд ихэд санаа тавьдаг гэж зарим хүн хэлдэг. Тэгвэл Би яагаад түүнийг сонгосонгүй вэ? гэж зарим хүн хэлдэг. Энэ ч бас Миний захиргааны зарлиг юм. Хэрэв Би хэн нэгэн хүнийг Миний зүрх сэтгэлд нийцтэй байна гэвэл тэр хүн Миний зүрх сэтгэлд нийцтэй агаад Миний хайртай хүн байна; хэрэв би хэн нэгэн хүнийг Сатаны үр сад байна гэвэл, тэр хүн Миний үзэн яддаг нэгэн юм. Хэнд ч бүү тал зас! Чи тэр хүнийг нэвт харж үнэхээр чадах уу? Эдгээрийг бүгдийг нь Би шийддэг юм. Хөвгүүн үргэлж хөвгүүн, Сатан үргэлж Сатан байдаг; өөрөөр хэлбэл, хүний уг чанар өөрчлөгддөггүй. Би өөрчлөхгүй л бол бүгд өөр өөрсдийн төрлийг дагадаг, хувиршгүй юм!

Миний ажил урагшлахын хэрээр Би та нарт Өөрийн нууцыг илчилдэг. Миний ажил аль алхам хүртэл урагшилсныг та нар үнэндээ мэдэх үү? Миний хийдгийг

хийж, Миний хэлдгийг хэлэхийн тулд үнэхээр Миний Сүнсийг дагах уу? Би яагаад Хятадыг Миний хараасан улс гэдэг вэ? Нэгдүгээрт, Би өнөөдрийн хятад хүмүүсийг Өөрийн төрхөөр бүтээсэн. Тэдэнд сүнс гэж байгаагүй, эртнээс Сатанаар завхруулагдаад, аврагдаж чадаагүй. Ийм шалтгааны улмаас Би энэ хүмүүст ихэд уурсаж, хараасан юм. Энэ хүмүүс агуу улаан лууны үр сад учраас Би тэднийг хамгаас их үзэн ядаж, тэднийг дурдах болгонд уур хүрдэг. Энэ нь дэлхийн улс орнууд Хятадыг нэгтгэсэн эринийг санагдуулдаг. Өнөөдөр ч бас адил, энэ бүгд Миний хараал—агуу улаан лууны эсрэг Миний хамгийн хүчирхэг шүүлт байсан. Эцэст нь Би өөр нэг төрлийн хүнийг бий болгож, тэдний дундаас Өөрийн ууган хөвгүүд, хөвгүүд, ардууд, Надад үйлчлэл үзүүлдэг хүмүүсийг урьдчилан тогтоосон. Тиймээс Миний өнөөдөр хийдэг бүхнийг Би аль эрт зохицуулсан. Хятадад эрх барьж байгаа хүмүүс яагаад та нарыг ахин дахин хавчиж дарангуйлдаг вэ? Яагаад гэвэл агуу улаан луу Миний хараалд дургүйцэж, Намайг эсэргүүцэж байгаа юм. Гэвч яг ийм хавчлага, аюул занал дор Би Өөрийн ууган хөвгүүдийг бүрэн төгс болгодог, ингэснээр агуу улаан луу болон түүний үр садын эсрэг хүчтэй хариу цохилт өгч болно. Дараа нь Би тэднийг ангилна. Одоо Миний үгийг сонссоны дараа, Өөртэйгөө хамт хаанчлахыг зөвшөөрсний минь ач холбогдлыг та нар үнэхээр ойлгож байна уу? Агуу улаан лууг үхэл рүү нь бүрмөсөн унагаалаа гэж Миний хэлэх үе нь мөн Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчлах цаг үе юм. Агуу улаан луу ууган хөвгүүдийг хавчсанаараа Надад ихээхэн үйлчлэл хийж байна, Миний хөвгүүд өсөж том болоод Миний гэрийн хэрэг явдлыг зохицуулж чаддаг болмогц тэдгээр хорон муу зарцыг (үйлчлэл үзүүлэгчдийг) хөсөр хаях болно. Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчилж, Миний санаа зорилгыг биелүүлсэн байх учир Би үйлчлэл үзүүлэгчдийг нэг нэгээр нь гал, хүхрийн нуур луу түлхэн унагана: Ямар ч үнээр хамаагүй, тэднийг явуулах ёстой! Сатаны төрлийнхөн бас Миний ерөөлийг эдлэхийг хүсдэг, Сатаны эзэмшил дор буцаж очихыг хүсдэггүйг Би сайн мэднэ; гэхдээ хүн бүрийн дагаж мөрдөх ёстой, хэрэгжүүлэх ёстой, хэнийг ч хэлтрүүлэхгүй Миний захиргааны зарлиг гэж Надад бий. Та нарыг зөрчүүлэхгүй байхын тулд Би Өөрийн захиргааны зарлигийг нэг нэгээр нь та нарт хэлнэ.

88-Р БҮЛЭГ

Миний алхаа хэдий хүртэл хурдассаныг хүмүүс ердөө төсөөлж чадахгүй: Хүний ой тойнд багтахааргүй гайхамшиг тохиосон нь энэ юм. Дэлхий ертөнцийн бүтээлээс хойш Миний алхаа үргэлжилж, Миний ажил хэзээ ч зогсоогүй. Орчлон ертөнц бүхэлдээ өдрөөс өдөрт өөрчлөгдөж, хүмүүс ч бас тогтмол өөрчлөгдөж байна. Энэ бүгд Миний ажил, Миний төлөвлөгөөний хэсэг, тэр ч бүү хэл Миний удирдлагад хамаардаг гэдгийг хэн ч мэдэж, ойлгодоггүй. Намайг Өөрөө та нарт хэлж, та нартай нүүр нүүрээ харан ярилцахад л та нар жаахан мэддэг; өөрөөр бол Миний удирдлагын

төлөвлөгөөний төслийг ерөөсөө хэн ч мэддэггүй. Хэний ч өөрчилж чадахгүй Миний агуу хүч чадал, үүнээс ч илүүтэйгээр Миний гайхалтай үйлдэл ийм билээ. Иймээс өнөөдөр Миний хэлсэн зүйл биелдэг, үүнийг зүгээр л өөрчилж болохгүй. Хүний үзэлд Миний тухай өчүүхэн ч мэдлэг байдаггүй—тэр чигтээ л учир утгагүй дэмий яриа байдаг! Өөрсдийгөө ханаж, цадсан гэж бүү бод! Би чамд хэлье, чи үнэхээр болоогүй байна! Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөнөөс та нар ердөө өчүүхэн багыг мэддэг, иймээс та нар Миний хэлэхийг сонсож, хий гэснийг минь хийх ёстой. Бүх зүйл дээр Миний хүслийн дагуу үйлдвэл Миний ерөөлийг лавтай хүртэх болно; итгэдэг хэн ч бай, хүлээн авч чадна, харин итгэдэггүй хэний ч бай төсөөлсөн “юу ч биш зүйл” өөрт нь биелэх болно. Энэ бол Миний зөвт байдал, түүнээс ч илүүтэйгээр, Миний сүр жавхлан, уур хилэн, бас гэсгээлт билээ. Би хэний ч нэг ч бодол, үйлдлийг өршөөхгүй.

Миний үгийг сонсоод ихэнх хүн айж, санаа зовон духаа үрчийлгэж, салгалан чичирдэг. Би чамд буруу зүйл хийсэн үү? Чи агуу улаан лууны үр сад биш байж болно гэж үү? Чи сайн байх гэж бүр дүр эсгэж байна! Бүр Миний ууган хүүгийн дүр эсгэж байна! Чи Намайг сохор гэж бодоо юу? Намайг хүмүүсийг хооронд нь ялгаж чадахгүй гэж бодоо юу? Би бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан байна: Би хөвгүүддээ, бас агуу улаан лууны үр сад болох та нарт ингэж хэлдэг. Би бүх зүйлийг тодорхой, өчүүхэн ч алдаа гаргалгүйгээр хардаг. Би хийдэг зүйлээ яахан мэдэхгүй байж болох билээ? Миний хийдэг зүйлс Надад тов тодорхой байна! Би яагаад Өөрийгөө орчлон ертөнц болон бүх зүйлийн Бүтээгч, Бурхан Өөрөө гэдэг вэ? Би яагаад Өөрийгөө хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан гэдэг вэ? Би хүн бүрийн нөхцөл байдлыг сайн мэднэ. Та нар Намайг юу хийх, юу хэлэхээ мэддэггүй гэж бодоо юу? Энэ та нарын санаа тавих зүйл биш—Миний гарт үхэхээс болгоомжил; тэгвэл чи хохирол амсана. Миний захиргааны зарлиг өршөөдөггүй. Ойлгов уу? Дээрх бүгд нь Миний захиргааны зарлигийн хэсгүүд юм. Урьд нь та нар ойлгоогүй байсан учраас эдгээрийг та нарт хэлсэн өдрөөс эхлэн цаашид ямарваа гэмт хэрэг үйлдвэл залхаан цээрлүүлэх болно.

Одоо Би Өөрийн захиргааны зарлигийг та нарт сонордуулъя (өөр өөр хүмүүст өөр өөр гэсгээлт оноох бөгөөд сонордуулсан өдрөөсөө хүчинтэй):

Би хэлсэндээ хүрдэг, бүх зүйл Миний гарт байдаг: Эргэлзсэн хэн ч бай гарцаагүй хороогдох болно. Ямар ч бодолцох зүйл гэж байхгүй; тэднийг нэн даруй сөнөөж, Миний зүрх сэтгэлээс үзэн ядалтыг үгүй хийнэ. (Хороогдсон хэн ч болов Миний хаанчлалын гишүүдийн нэг биш, Сатаны үр удам байх ёстой гэдэг нь үүнээс хойш баталгаажиж байна.)

Та нар ууган хүүгийн хувиар өөрсдийн байр суурийг хадгалж, үүргээ сайн биелүүлж, бусдын хэрэгт хошуу дүрэхгүй байх ёстой. Та нар Миний удирдлагын төлөвлөгөөнд өөрсдийгөө өргөн барьж, хаа ч явсан Надад сайн гэрчлэл хийж, Миний нэрийг алдаршуулах хэрэгтэй. Ичгүүртэй үйл бүү хий, харин Миний хөвгүүд, Миний ардуудад үлгэр жишээ бол. Хором ч болов цадиггүй бүү бай: Та нар хүн

бүрд барлаг шиг бус, ууган хүүгийн хувиар харагдаж, харц дээгүүр урагш алхах, ёстой. Миний нэрийг гутаах биш харин алдаршуулахыг Би та нараас хүсэж байна. Ууган хүү болсон хүмүүс бүхнийг хийж чадахгүй, харин тус бүрдээ өөрийн гэсэн үүрэгтэй. Энэ бол Миний та нарт өгсөн зайлсхийж болохгүй үүрэг хариуцлага. Та нар Миний даалгасан зүйлсийг биелүүлэхэд бүх зүрх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүчин чадлаа зориулах ёстой.

Энэ өдрөөс хойш орчлон ертөнц даяар Миний бүх хүү, Миний бүх ардыг хариулах үүргийг биелүүлэх нь Миний ууган хөвгүүдэд оногдох бөгөөд үүнийг биелүүлэхэд бүхий л зүрх сэтгэл, бүхий л оюун ухаанаа зориулж чадаагүй хэнийг ч бай Би гэсгээнэ. Энэ бол Миний зөвт байдал—Би Өөрийн ууган хөвгүүдийг ч өршөөж, зөөлөн хандахгүй.

Хэрэв Миний хөвгүүд, Миний ардууд дунд Миний ууган хөвгүүдийн нэгийг дооглож, доромжилдог хүн байвал Би хатуу шийтгэнэ, учир нь Миний ууган хөвгүүд Намайг төлөөлдөг бөгөөд тэдэнд яаж хандана, Надад бас тэгж хандаж байгаа хэрэг. Энэ бол Миний захиргааны зарлигуудын хамгийн хатуу чанга нь юм. Миний хөвгүүд, Миний ардуудын дунд энэ зарлигийг зөрчсөн хэнд ч бай, Миний зөвт байдлыг хүссэнээрээ хэрэгжүүлэхийг Би Өөрийн ууган хөвгүүдэд зөвшөөрнө.

Намайг өнгөцхөнөөр хардаг; Миний хоол унд, хувцас хунар, нойронд л анхаардаг; Миний ачааг хайхардаггүй, Миний гадаад хэрэгт л оролцдог, өөрсдийн үүргийг зохистой биелүүлэхэд анхаарал хандуулдаггүй хэнийг ч Би аажмаар хаядаг. Энэ нь чихтэй бүхэнд хамаатай.

Надад үйлчлэл хийж дууссан хэн ч бай, хэл ам гаргалгүй дуулгавартайгаар буцах ёстой. Болгоомжтой бай, эс бөгөөс Би чамайг журамлах болно. (Энэ бол зарлигийн нэмэлт.)

Одооноос Миний ууган хөвгүүд төмөр саваг авч, бүх улс үндэстэн, ард түмнийг захирах Миний эрх мэдлийг хэрэгжүүлж, бүх улс үндэстэн, ард түмний дунд алхаж, Миний шүүлт, зөвт байдал, сүр жавхланг бүх улс үндэстэн, ард түмний дунд хэрэгжүүлж эхэлнэ. Миний удирдлагын төлөвлөгөө биелж, Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчилж чаддаг учраас Миний хөвгүүд, Миний ардууд зогсолтгүй Надаас эмээж, Намайг магтаж, Намайг уухайлж, Намайг алдаршуулах болно.

Энэ бол Миний захиргааны зарлигийн нэг хэсэг бөгөөд ажил урагшлахын хирээр дараа нь Би та нарт тэдгээрийг хэлэх болно. Дээрх захиргааны зарлигаас та нар Миний ажлаа хийдэг хурдыг, мөн Миний ажил ямар алхамд хүрснийг харах болно. Энэ бол баталгаа билээ.

Би аль хэдийн Сатаныг шүүсэн. Миний хүсэл саадгүй, бас Миний ууган хөвгүүд Надтай хамт алдрыг олж авсан тул Би Сатанд харьяалагддаг бүх зүйл болон ертөнцөд Өөрийн зөвт байдал, сүр жавхланг аль хэдийн хэрэгжүүлсэн. Би Сатанд анхаарал огт хандуулдаггүй, хуруугаа ч хөдөлгөдөггүй (учир нь тэр Надтай ярих гавьяагүй). Би зүгээр л хийхийг хүссэн зүйлээ хийсээр байдаг. Миний ажил алхам алхмаар төвөггүй урагшилж, Миний хүсэл бүх газарт саадгүй байна. Энэ нь

Сатаныг тодорхой хэмжээнд шившиглэж, бүрэн устгасан ч, Миний хүслийг биелүүлээгүй. Би мөн Өөрийн захиргааны зарлигийг тэдэн дээр хэрэгжүүлэхийг Өөрийн ууган хөвгүүдэд зөвшөөрдөг. Нэг талаар, Би Сатанд өөрт нь хандсан уур хилэнгээ харуулдаг; нөгөөтээгүүр Би түүнд Өөрийн алдар сууг харуулдаг (Миний ууган хөвгүүд бол Сатаны доромжлолын хамгийн цангинасан гэрчлэгч нар гэдгийг харуулдаг). Би түүнийг биечлэн шийтгэдэггүй, харин Өөрийн ууган хөвгүүдэд Миний зөвт байдал, сүр жавхланг хэрэгжүүлэх боломж олгодог. Сатан Миний хөвгүүдэд зүй бусаар хандаж, Миний хөвгүүдийг хавчиж, дарладаг байсан учир өнөөдөр түүний үйлчлэл дууссаны дараа Би нас бие гүйцсэн, Өөрийн ууган хөвгүүдэд түүнийг журамлах зөвшөөрөл олгоно. Сатан уналтын эсрэг хүчгүйдсэн. Дэлхий дээрх бүх улс үндэстний зогсонги байдал бол үүний хамгийн сайн гэрч; тулалдаж буй хүмүүс, дайн дажинтай улс орнууд бол Сатаны хаанчлал нуран унасны илэрхий шинж. Би өмнө нь ямар ч тэмдэг, гайхамшиг үзүүлээгүйн шалтгаан нь Сатаныг шившиглэж, Өөрийн нэрийг алхам алхмаар алдаршуулах гэснийх юм. Сатаныг бүрэн устгасны дараа Би Өөрийн хүчийг үзүүлж эхэлнэ: Миний хэлсэн зүйл биелж, хүний үзэлтэй нийцэхгүй ер бусын зүйлс биелэх болно (энэ нь удахгүй ирэх ерөөлийг хэлж байна). Би бол бодитой Бурхан Өөрөө агаад Надад дүрэм гэж үгүй, Би Өөрийн удирдлагын төлөвлөгөөн дэх өөрчлөлтийн дагуу ярьдаг тул өнгөрсөнд Миний хэлсэн зүйл өнөөдөрт хамаарах албагүй. Өөрсдийн үзэлтэй бүү зууралд! Би дүрэм дагадаг Бурхан биш. Надтай байхад бүх зүйл чөлөөтэй, ер бусын, бас бүрэн чөлөөлөгдсөн байдаг. Магадгүй өчигдөр хэлсэн зүйл өнөөдөр хуучирч эсвэл хөсөр хаягдаж магад (гэвч Миний захиргааны зарлиг тунхаглагдсанаасаа хойш хэзээ ч өөрчлөгдөхгүй). Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний алхмууд юм. Дүрэм журамтай бүү зууралд. Өдөр бүр шинэ гэрэл, шинэ илчлэл байдаг ба тэр бол Миний төлөвлөгөө. Өдөр бүр Миний гэрэл чамд илчлэгдэж, Миний дуу хоолой орчлон ертөнцөд гарах болно. Ойлгов уу? Энэ бол чиний үүрэг, Миний чамд даалгасан хариуцлага. Чи үүнийг хором ч огоорох ёсгүй. Би Өөрийн сайшаадаг хүмүүсийг эцсээ хүртэл ашиглах бөгөөд энэ хэзээ ч өөрчлөгдөхгүй. Би төгс хүчит Бурхан учир ямар хүн юу хийх ёстой, ямар хүн юу хийх чадвартайг мэднэ. Энэ бол Миний бүхнийг чадагч чанар юм.

89-Р БҮЛЭГ

Юм бүхнийг Миний санаа зорилгын дагуу хийнэ гэдэг амаргүй. Энэ бол өөрийгөө албадаж дүр эсгэх асуудал биш; харин дэлхий ертөнцийг бүтээхээсээ өмнө Би чамд Өөрийн хэв чанарыг хайрласан эсэхээс хамаардаг. Энэ бүх зүйл Надаас шалтгаалдаг. Энэ бол хүмүүсийн хийж чадах зүйл биш. Би хайрлахыг хүсдэг хүмүүсээ хайрладаг, Миний ууган хөвгүүн гэсэн хэн боловч ууган хөвгүүн лавтай мөн. Энэ бол яг зөв! Чи дүр үзүүлэхийг хүсэж болох ч тэгэх нь талаар болно! Би чиний юу болохыг таньж чадахгүй гэж бодоо юу? Миний өмнө байхдаа зарим

нэг сайн зан авир гаргахад хангалттай юу? Ийм энгийн гэж үү? Хэрхэвч үгүй; чамд Миний амлалт, Миний урьдчилан тогтоолт байх ёстой. Миний ар хударгаар юу хийдгийг чинь мэддэггүй гэж бодоо юу? Эх захаа алдсан юм! Надад хийх үйлчлэл чинь дуусмагц гал, хүхрийн нуурандаа үтэр түргэн буц! Чамайг харахаас ч ой гутаж, зэвүү хүрч байна. Надад үйлчилдэг бүх хүн, Миний төлөө өөрийгөө үнэнчээр зарлагаддаггүй, задарсан, цадиггүй, Миний санаа зорилгыг ойлгодоггүй бүх хүн үйлчлэлээ дууссаны дараа үтэр түргэн Миний нүднээс далд ор! Эс бөгөөс Би чамайг өшиглөж гаргана! Энэ хүмүүс Миний гэрт (өөрөөр хэлбэл, чуулганд) дахиад нэг хором ч байж болохгүй. Миний нэрийг шившиглэж, Миний нэр хүндийг унагахгүйн тулд тэд бүгд эндээс явах ёстой. Энэ хүмүүс бүгд агуу улаан лууны үр удам; Миний удирдлагад саад хийлгэхээр агуу улаан луу тэднийг илгээсэн юм. Тэд Миний ажлыг үймүүлэх ов мэхэнд гаршсан. Хүү минь! Чи үүнийг нэвт харах ёстой! Ийм хүмүүстэй бүү нийл. Ийм төрлийн хүмүүсийг харах үедээ урхинд нь орохоос зайлсхийхийн тулд хурдан холд; урхинд нь орвол аминд чинь хор хүргэнэ! Хайхрамжгүй ярьдаг, бодолгүйгээр үйлддэг, зүгээр л наргиж инээдэг, хоосон хов ярьдаг хүмүүсийг Би хамгийн их жигшдэг. Би энэ хүмүүсийн хэнийг нь ч хүсдэггүй; тэд бүгд Сатаны төрлийнхөн! Тэд ямар ч шалтгаангүй доог тохуу хийдэг. Энэ ямар гээч амьтад вэ? Тэд дэмий хоосон юм ярьж, эх захгүй авирладаг. Тэдэнд ичих сэтгэл төрөхгүй л байна уу? Үнэн хэрэгтээ, ийм хүн хамгийн үнэ цэнгүй бөгөөд Би тэднийг аль эрт нэвт харж, орхисон. Тэгээгүй бол тэд Миний сахилгажуулалтад өртөлгүйгээр ахин дахин дэмий хоосон зүйл юу гэж ярих вэ дээ? Тэд бол үнэхээр агуу улаан лууны үр удам! Одоо, Би эдгээрийг нэг нэгээр нь зайлуулж эхэлсэн. Би Сатаны үр удмыг Өөрийн ууган хөвгүүд, Өөрийн хөвгүүд, ардууд болгон ашиглаж чадах уу? Тэгвэл Би мунгинасан хэрэг болох бус уу? Би яавч тэгэхгүй. Та нар үүнийг тодорхой ойлгов уу?

Өнөөдөр та нарт тулгарсан бүх зүйлийг сайн ч бай, муу ч бай, бүгдийг нь Миний ухаалаг гар зохицуулсан; Би бүгдийг зохион байгуулж, хяналтдаа байлгадаг. Энэ бол хүн төрөлхтний амархан гүйцэлдүүлж чадах зүйл яавч биш. Зарим хүн Миний тухай санаа зовж, гарын алга нь хөлөрсөөр л байдаг боловч тэд үнэхээр санаа зовох хэрэггүй! Тэд гол ажлаа огоорч, сүнсэнд орохоор эрж хайдаггүй атлаа амийн өсөлтийг хүссээр байдаг. Тэд хий дэмий найдаж байна! Тэд огт сэтгэл түгшдэггүй атлаа Миний хүслийг хангахыг хүсэж л байдаг! Чи Миний өмнөөс санаа зовдог боловч Би санаа зовдоггүй. Чи юунд санаа зовно вэ? Миний төлөөх ажил чинь хааш яаш бөгөөд чи улайм цайм худал хэлдэг. Би чамд хэлчихье! Энэ мөчөөс эхлэн Би чам шиг ийм хүмүүсийг Өөрийн гэрээс хөөн гаргах болно. Тийм хүмүүс Миний гэрт Надад үйлчлэхэд тэнцэхгүй. Намайг үйлдлээрээ доромжилдог учраас Би тэднийг жигшдэг. “Миний эсрэг доромжлол бол өршөөхийн аргагүй нүгэл” гэж хэлэх үед хэнийг хэлж байсан бэ? Та нар үүнийг тодорхой ойлгож байна уу? Иймэрхүү хүн аль эрт энэ нүглийг үйлдсэн атлаа асуудал хараахан ноцтой болоогүй гэж боддог. Энэ мунгинасан хүн үнэхээр сохор, мэдлэггүй, сүнс нь хаалттай юм! Би чамайг хөөж гаргана! (Сатан Намайг сорьж байгаа нь энэ тул Би үүнийг маш их үзэн яддаг

бөгөөд энэ сэдэв ахин дахин хөндөгдөж, тухай бүрдээ Намайг хилэгнүүлсээр ирсэн. Би ууpаа барьж чадахгүй, үүнийг хэн ч зогсоож дийлэхгүй. Цаг нь хараахан ирээгүй байна, эс бөгөөс Би тэр хүнтэй аль эрт харьцчихсан байх байсан юм!) (Энэ нь, одоо гаднынхан Хятадад бөөнөөрөө орж ирэхээр хичээнэ гэдэгт итгэдэггүй олон хүн байгаа баримтын тухай юм; тэд одоо ч гэсэн итгэхгүй хэвээр байгаа нь Миний уур хилэнг хүргэж, дэвэргэдэг.)

Миний гэр дотор яг ямархуу хүн Миний зүрх сэтгэлийн дагуу байдаг вэ? Өөрөөр хэлбэл, Би бүтээлээс өмнө ямар төрлийн хүмүүсийг Өөрийн гэрт мөнх амьдруулахаар урьдчилан тогтоосон бэ? Та нар мэдэх үү? Та нар Намайг ямар хүмүүсийг хайрладаг, ямар хүмүүсийг үзэн яддаг тухай бодож үзсэн үү? Надтай үзэл бодол нэгтэй, сайхан цаг уе, зовлон бэрхшээлийг Надтай хуваалцдаг, өөрөөр хэлбэл, ерөөл, зовлон бэрхшээлийн аль алийг нь хуваалцдаг хүмүүст Миний гэр зориулагдсан юм. Энэ хүмүүс бүгд Миний хайрладгийг хайрлаж, Миний үзэн яддагийг үзэн ядаж чадна Миний жигшдэг зүйлийг тэд орхиж чаддаг. Би тэдэнд идэж болохгүй гэж хэлбэл тэд Миний санаа зорилгыг биелүүлэхийн тулд ходоод хоосон явахад ч бэлэн байдаг. Ийм хүн Надад үнэнч үлдэж, Миний төлөө өөрийгөө зарлагадахад бэлэн байж, Миний уйгагүй хүчин чармайлтад санаа тавьж, Миний төлөө үргэлж шаргуу ажиллаж чадна. Иймээс Би ийм төрлийн хүнд ууган хүүгийн байр суурь болон Өөрт буй бүхнээ өгдөг: Би бүх чуулганыг удирдах чадвартай, үүнийгээ тэдэнд өгдөг; Би мэргэн ухаантай, үүнийгээ ч бас тэдэнд өгдөг; Би үнэнийг хэрэгжүүлэхийн төлөө зовж чадна, бас Би энэ хүмүүст шийдэмгий байдал өгч, Миний төлөө бүхнийг туулж чаддаг болгоно; Би сайн хэв чанартай, үүнийгээ тэдэнд өгч, бусад хүн тэднээс Намайг олж хараг гэсэндээ тэднийг яг Өөртэйгөө адил, өчүүхэн ч ялгаагүй болгоно. Одоо Би бүрэн бурханлаг чанарын минь нэг талыг амьдран харуулах боломж олгохын тулд Өөрийн бүрэн бурханлаг чанарыг энэ хүмүүсийн дотор оруулж байна, ингэснээр тэд Намайг бүрэн илэрхийлж чадна; энэ бол Миний санаа зорилго. Гадаад талаараа Над шиг байх гэж бүү хөөцөлд (Надтай адилхан идэж, эсвэл Надтай адил хувцас өмсөх); энэ бүхэн нэмэргүй бөгөөд ийм зүйлсээр хөөцөлдвөл та нар өөрсдийгөө л сүйрүүлнэ. Учир нь гаднаа Намайг даган дуурайх гэж чармайдаг хүмүүс бол Сатаны боолууд бөгөөд иймэрхүү хичээл зүтгэл нь Сатаны явуулга; Сатаны санаархлын тусгал юм. Чи Надтай адил байхаар чармайдаг, гэхдээ чи зохистой юу? Би чамайг үхтэл чинь дэвслэх болно! Миний ажил байнга хэрэгжиж, дэлхий дахины улс үндэстэн бүрд өргөжиж байна. Миний мөрийг хурдан дага!

90-Р БҮЛЭГ

Сохор хүмүүс бүгд дахиад ганц хором ч үлдэлгүй Надаас явах ёстой, учир нь Намайг мэдэж чаддаг, Намайг харж чаддаг, Надаас бүх зүйлийг олж авч чаддаг хүмүүсийг л Би хүсдэг. Тэгвэл хэн Надаас үнэхээр бүх зүйлийг олж авч чадах вэ?

Ийм төрлийн хүн гарцаагүй маш цөөн бөгөөд тэд Миний ерөөлийг хүртэх нь лавтай. Би энэ хүмүүст хайртай бөгөөд Өөрийн баруун гар, Өөрийн илрэл болгох гэж нэг нэгээр нь шилж сонгоно. Энэ хүмүүсийн төлөө Би бүх улс үндэстэн, бүх ард түмнээр Өөрийгөө зогсолтгүй магтуулж, уухайлуулсаар байх болно. Өө, Сион уул аа! Ялалтын туг мандуулж, Намайг уухайлаач! Учир нь Би орчлон ертөнц, газар дэлхийн зах хязгаарыг хөндлөн гулд туулж, уул толгод, гол мөрөн, аливаа бүхний өнцөг булан бүрд оччихоод энд дахин нэгэнтээ эргэн ирж байна. Би зөвт байдал, шүүлт, уур хилэн, шатаалттайгаар, үүнээс ч илүүтэйгээр Өөрийн ууган хөвгүүдтэй хамт ялгууснаар эргэн ирдэг. Би Өөрийн зэвүүцдэг бүх зүйл, Өөрийн жигшдэг бүх хүн, хэрэг явдал, эд зүйлсийг хол хаясан. Би ялгуусан бөгөөд хийе гэсэн бүхнээ хийж дуусгасан. Намайг Өөрийн ажлыг дуусгаагүй гэж хэн хэлж зүрхлэх вэ? Намайг Өөрийн ууган хөвгүүдийг олж аваагүй гэж хэн хэлж зүрхлэх вэ? Намайг ялгууснаар эргэн ирээгүй гэж хэн хэлж зүрхлэх вэ? Тэгсэн хүмүүс гарцаагүй Сатаны төрөл мөн; тэд бол Миний өршөөлийг олж авахад хэцүү санагддаг хүмүүс юм. Тэд бол Миний хамгаас их үзэн яддаг сохрууд, бузар чөтгөрүүд юм. Эдгээрт Би Өөрийн уур хилэн, Өөрийн шүүлтийг бүхэлд нь илчилж эхлэн, шатаж байгаа галаараа дамжуулан орчлон ертөнц, газар дэлхийн нэг зах хязгаараас нөгөөг хүртэл асааж, өнцөг булан бүрийг гэрэлтүүлнэ—энэ бол Миний захиргааны зарлиг.

Чи Миний үгийг ойлгомогцоо тэдгээрээс тайтгарал авах хэрэгтэй; үүнийг анхааралгүй өнгөрөөх ёсгүй. Шүүлтийн айлдвар өдөр бүр тохиож байхад, та нар яагаад ийм мулгуу, хөшүүн байдаг юм бэ? Яагаад та нар Надтай хамтран ажилладаггүй юм бэ? Там руу явахыг тэгтлээ хүсээд байна уу? Би бол Өөрийн ууган хөвгүүд, Өөрийн хөвгүүд, ардуудад өршөөнгүй Бурхан гэж Намайг хэлэхэд, үүнийг та нар юу гэж ойлгож байна вэ? Энэ бол энгийн мэдэгдэл бус, үүнийг эерэг өнцгөөс ойлгох хэрэгтэй. Өө, сохор хүн төрөлхтөн! Би та нарыг олон ч удаа аварч, Миний амлалтыг олж аваг гэж Сатаны савраас, бас гэсгээлтээс гаргасан байтал та нар яагаад Миний зүрх сэтгэлд огт санаа тавьдаггүй юм бэ? Та нарын хэн нь ч болов энэ маягаараа аврагдаж чадах уу? Миний зөвт байдал, сүр жавхлан, шүүлт Сатанд огт өршөөл үзүүлдэггүй. Харин та нарын тухайд тэдгээр нь та нарыг аврах зорилготой байдаг ч та нар Миний зан чанарыг ойлгож ер чаддаггүй, Миний үйлдлийн цаад зарчмыг ч мэддэггүй. Та нар Намайг Өөрийн янз бүрийн үйлдлийн хэр ноцтойг ялгадаггүй, бас үйлдлийнхээ байг ялгадаггүй гэж бодсон—яасан мэдлэггүй юм бэ! Би бүх хүн, үйл явдал, юмсыг тодорхой харах чадвартай. Би хүн бүрийн гол чанарыг бүрэн тодорхой ойлгодог, өөрөөр хэлбэл, хүний дотроо өвөрлөдөг бүхнийг бүрэн нэвт хардаг. Би хүнийг иезебел эсвэл янхан эсэхийг тодорхой хардаг бөгөөд хэн нууцаар юу хийдгийг мэднэ. Миний өмнө сэтгэл татам байдлаа бүү гайхуул, өөдгүй амьтан минь! Одоо эндээс зайл! Өөрийн нэрийг шившиг болгохоос зайлсхийхийн тулд Би ийм хүнийг огт ашиглахгүй! Тэд Миний нэрд гэрчлэл хийж чадахгүй, харин ч эсрэгээрээ үйлдэж Миний гэр бүлд гутамшиг авчирдаг! Тэднийг Миний гэрээс нэн даруй хөөх учиртай. Тэд Надад хэрэггүй. Би

ганц ч секунд хойшлуулахыг тэвчихгүй! Миний хаанчлалд бүгд аль ч талаараа ариун, өө сэвгүй тул тэр хүмүүс яаж ч эрж хайгаад нэмэргүй. Өөрийн ардуудыг оролцуулаад, хэрвээ Би хэн нэгнийг хэрэггүй гэж хэлбэл, хэрэггүй л гэсэн үг; Намайг бодлоо өөрчилнө гэж бүү хүлээ. Өмнө нь Надад хэчнээн сайн байсан чинь Надад хамаагүй!

Би та нарт өдөр бүр нууц илчилдэг. Та нар Миний үг хэлдэг аргыг мэдэх үү? Би Өөрийн нууцыг юун дээр үндэслэж илчилдэг вэ? Та нар мэдэх үү? Та нар үргэлж Намайг өөрсдийг чинь зөв цагт хангадаг Бурхан гэцгээдэг, тэгвэл та нар эдгээр талыг юу гэж ойлгож байна? Би Өөрийн ажлын алхамд нийцүүлэн Өөрийн нууцыг нэг нэгээр нь та нарт илчилж, Өөрийн төлөвлөгөөний дагуу, үүнээс ч илүүтэйгээр бодит биеийн хэмжээнд чинь нийцүүлж та нарыг хангадаг (Миний хангалтыг дурдах болгонд хаанчлал дахь хүн нэг бүрд хамаатуулдаг). Миний үг хэлэх арга ийм байдаг: Өөрийн гэр дэх хүмүүст Би тайтгарал өгч, тэднийг хангаж, шүүдэг; Сатанд Би өчүүхэн ч өршөөл үзүүлдэггүй, бүгд уур хилэн, шатаалт байдаг. Би Өөрийн урьдчилан тогтоогоогүй, сонгоогүй хүмүүсийг Өөрийн гэрээс нэг нэгээр нь хөөхийн тулд Өөрийн захиргааны зарлигийг ашиглах болно. Сэтгэл түгших хэрэггүй. Би тэднийг анхны төрхөө илчлэхэд хүргэмэгц (төгсгөл ирэхэд тэд Миний хөвгүүдэд үйлчлэл үзүүлсний дараа) тэд ёроолгүй нүхэнд буцаж орно, эс бөгөөс Би энэ асуудлыг хэзээ ч зүгээр орхихгүй, хэзээ ч өнгөрөөхгүй. Хүмүүс үргэлж там болон Үхэгсдийн орныг дурддаг. Гэхдээ энэ хоёр үг юуг хэлдэг вэ, тэдгээрийн хоорондох ялгаа юу вэ? Тэдгээр нь үнэхээр хүйтэн, харанхуй буланг хэлдэг гэж үү? Хүний оюун санаа үргэлж Миний удирдлагыг тасалдуулж, санамсаргүй эргэцүүлснийгээ тун сайн гэж боддог. Гэхдээ тэдгээр нь бүгд өөрсдийнх нь төсөөллөөс өөр юу ч биш. Үхэгсдийн орон, там гэдэг нь хоёулаа Сатан болон муу ёрын сүнсний амьдарч байсан бузар сүмийг хэлдэг. Өөрөөр хэлбэл, өмнө нь Сатан болон муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн хэн ч бай, өөрсдөө там, өөрсдөө Үхэгсдийн орон юм—энэ эндүүрэл биш! Иймээс Би бузар сүмд амьдардаггүй гэдгээ өмнө нь ахин дахин онцолсон. Би (Бурхан Өөрөө) Үхэгсдийн оронд юм уу тамд амьдарч болно гэж үү? Тэгвэл хөгийн, утгагүй хэрэг болох бус уу? Би үүнийг хэд хэдэн удаа хэлсэн боловч юу гэсэн утгатайг нь та нар ойлгохгүй л байна. Тамтай харьцуулбал Үхэгсдийн орныг Сатан илүү ноцтой завхруулдаг. Үхэгсдийн орны хүмүүс хамгийн ноцтой бөгөөд Би тэр хүмүүсийг зүгээр л урьдчилан тогтоогоогүй; тамын хүмүүс бол Миний урьдчилан тогтоосон ч дараа нь таягдан хаядаг хүмүүс юм. Энгийнээр хэлбэл, Би энэ хүмүүсийн нэгийг нь ч сонгоогүй.

Хүмүүс Миний үгийг буруугаар ойлгохдоо мэргэжилтэн гэдгээ тогтмол харуулдаг. Хэрэв Би аливааг бага багаар хэлж өгч, тодруулаагүй бол та нарын дундаас хэн чинь ойлгох вэ? Та нар өмнө нь дурдаагүй зүйл байтугай Өөрийн минь хэлдэг үгэнд хүртэл дутуу хагас итгэдэг. Одоо бүх улс үндэстэнд дотоодын маргаан эхлээд байна: Ажилчид удирдлагатайгаа, оюутнууд багш нартайгаа, иргэд төрийн түшмэдтэй маргаж, үймээн самуун дэгдээдэг энэ мэт бүх үйл явдал улс үндэстэн бүрийн дотор

эхэлж үүсээд байгаа нь бүгд Надад хийх үйлчлэлийн нэгээхэн хэсэг юм. Тэгвэл эдгээр зүйлээр дамжуулан Надад үйлчлэл үзүүлдэг гэж Би яагаад хэлдэг вэ? Би хүмүүсийн золгүйтлээр бахаа хангадаг гэж үү? Би хайхрахгүй суудаг уу? Хэрхэвч үгүй! Учир нь энэ бол Сатан амь тавихын өмнө уурсан дайрч байгаа хэрэг бөгөөд энэ бүх зүйл нь сөрөг байдлыг ашиглан Миний хүч чадал, гайхамшигт үйл хэргийг товойлгогч болгох зорилготой юм. Энэ бүгд Надад хийж байгаа хүчирхэг гэрчлэл бөгөөд Сатан руу дайрах зэвсэг юм. Ертөнцийн бүх улс үндэстэн газар нутаг, нэр нөлөөний төлөө тэмцэж байх яг тэр үед Миний ууган хөвгүүд Миний хамтаар хаанчилж, тэдэнтэй харьцах болно, ийм хөөрхийлөлтэй орчин нөхцөлд Миний хаанчлал хүмүүсийн дунд бүрэн дүүрэн биеллээ олно гэдэг гарцаагүй тэдний төсөөллөөс давсан зүйл юм. Түүнчлэн, тэд эрх мэдлийн төлөө тэмцэлдэж, бусдыг шүүхийг хүсэж явахдаа өөрсдөө бусдад шүүгдэж, Миний уур хилэнд шатдаг—яасан өрөвдөлтэй вэ! Ямар өрөвдөлтэй вэ! Миний хаанчлал хүмүүсийн дунд биеллээ оллоо—ямар гайхалтай сайхан үйл явдал вэ!

Хүн болохын хувьд (Миний хаанчлалын хүмүүс ч бай, Сатаны үр удам ч бай), та нар бүгд Миний гайхамшигт үйл хэргийг үзэх ёстой, эс бөгөөс Би энэ асуудлыг хэзээ ч зүгээр өнгөрөөхгүй. Чи Миний шүүлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байсан ч гэсэн, Миний гайхамшигт үйл хэргийг үзээгүй л бол нэмэргүй л байх болно. Бүх хүн зүрх сэтгэлээрээ, үгээрээ, нүдээрээ үнэмших ёстой, хэнийг ч зүгээр өнгөрөөж болохгүй. Бүх хүн Надад алдар суу өгөх ёстой. Эцэстээ Би бүр агуу улаан лууг ч босгон, ялалтынхаа төлөө Өөрийгөө магтуулна. Энэ бол Миний захиргааны зарлиг—та нар санаж явах уу? Бүх хүн намайг эцэс төгсгөлгүй магтаж, Надад алдар суу өгөх ёстой!

91-Р БҮЛЭГ

Миний Сүнс Миний дуу хоолойгоор тогтмол ярьж, айлддаг—та нараас хэр олон чинь Намайг мэдэж чадах вэ? Яагаад Би махбод болж, та нарын дунд ирэх ёстой вэ? Энэ бол агуу нууц. Та нар өдөржин Намайг бодож, Надад тэмүүлэн, Намайг магтаж, Намайг таашааж, өдөр бүр Намайг идэж уудаг хэр нь өнөөдөр Намайг бас л мэддэггүй. Яасан мэдлэггүй, сохор юм бэ! Намайг ямар бага мэддэг юм бэ? Та нараас хэд чинь Миний хүсэлд хайхрамжтай хандаж чадах вэ? Өөрөөр хэлбэл, та нарын дундаас хэд чинь Намайг мэдэж чадах вэ? Та нар бүгд диаволын төрлийнх атлаа Миний хүслийг биелүүлэхийг хүссээр л байна уу? Мартаж үз! Сатаны үйлдэл хэчнээн сайн ч бай, бүгд Миний байгуулсныг нурааж, Миний удирдлагад саад хийх зорилготой байдаг гэдгийг Би чамд хэлчихье. Түүний үйлдэл хэчнээн сайн байлаа ч мөн чанар нь өөрчлөгддөггүй, Намайг эсэргүүцдэг. Тиймээс, олон хүн өөрийн мэдэлгүй Миний гарт цохиулан унаж, өөрийн мэдэлгүй Миний гэр бүлээс хөөгддөг. Өнөөдөр, ганц ч зүйлийг (их ч бай, бага ч бай) хүн зохион байгуулдаггүй; бүгд

Миний гарт байдаг. Хэрэв бүх зүйл хүний хяналтад байдаг гэж хэлбэл Би чамайг Намайг эсэргүүцдэг гэх бөгөөд чамайг гарцаагүй хатуу гэсгээж, үүрд хөл тавих газаргүй болгож орхино. Бүх үйл явдал, зүйлээс Миний гарт байдаггүй юу байна? Миний тогтоож, тодорхойлдоггүй юу байна? Гэтэл та нар Намайг мэдэх тухай ярьж л байдаг! Тэр чинь диаволын үг. Чи бусдыг хуурч чадсан юм чинь Намайг ч бас хуурч чадна гэж бодоо юу? Чиний хийсэн зүйлийг хэн ч мэдэхгүй бол юу ч болохгүй гэж бодоо юу? Амархан мултарчихна гэж бүү бод! Би чамайг Өөрийнхөө өмнө сөхрүүлж, бүгдийг нь яриулна. Ярихгүй байна гэдэг байж болшгүй; энэ бол Миний захиргааны зарлиг!

Та нар Миний Сүнс хэн болох, Миний махбод болсон бие хэн болохыг үнэхээр ойлгодог уу? Би бие махбодтой болохын ач холбогдол юу вэ? Та нарын хэн чинь ийм том асуудлыг хянуур тунгаан бодож, Надаас зарим нэг илчлэл хүлээн авсан бэ? Та нар бүгд өөрсдийгөө хуурч байна! Чамайг агуу улаан лууны үр сад гэж Би яагаад хэлдэг вэ? Өнөөдөр Би та нарт Өөрийн бие махбодтой болсны нууцыг илчилж байгаа бөгөөд дэлхий ертөнцийг бүтээгдсэнээс хойш хүний тайлж чадаагүй энэ нууц нь Миний үзэн ядалтын маш олон байг сүйрэлд хүргэсэн юм. Тэгээд өнөөдөр ч гэсэн хэвээр байна. Миний махбодын ачаар Миний хайртай олон хүн төгс болгуулсан. Би яг яагаад махбод болох ёстой вэ? Мөн яагаад Би одоогийнх шигээ харагддаг вэ (Миний өндөр, дүр төрх, биеийн хэмжээ зэргийг оролцуулаад)? Хэн энэ талаар юм хэлж чадах вэ? Би бие махбодтой болох нь асар их ач холбогдолтой тул үүнийг бүгдийг нь хэлэх аргагүй. Би одоо та нарт үүний нэг хэсгийг л хэлье (Миний ажлын алхмууд өдий хүрсэн тул Би үүнийг хийж, хэлэх ёстой): Би бие махбодтой болсон нь үндсэндээ Миний ууган хөвгүүдэд чиглэдэг, Би тэднийг хариулж, тэд Надтай нүүр тулан ярилцаж, ярьж чаддаг байхын төлөө байдаг; улмаар Би болон Миний ууган хөвгүүд ойр дотно байдаг (бид хамт идэж, хамт байж, хамт амьдарч, хамтдаа үйлдэл хийдэг гэсэн үг), ингэснээр тэд бодит байдал дээр Надаар тэжээлгэж чадна гэдгийг энэ нь харуулдаг—энэ нь хоосон үг биш, харин бодит байдал. Урьд нь хүмүүс Надад итгэдэг байсан боловч бодит байдлыг ухаарч чаддаггүй байсан нь Би бие махбод болоогүй байснаас үүдэлтэй юм. Өнөөдөр, Би бие махбодтой болсон нь та нарт бодит байдлыг ухаарах боломж олгож, Намайг чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүст Миний яриа, биеэ авч яваа байдал, асуудлыг зохицуулдгийн минь цаад зарчим зэргээс ухаалаг Бурхан Өөрөө—Намайг мэдэх боломж олгодог. Түүнчлэн, Намайг чин сэтгэлээсээ эрж хайдаггүй хүмүүст, Миний үл ажиглагдам үйлдлүүдээс Миний нэг тал болох хүн чанарыг минь харж, улмаар Намайг эсэргүүцэж, дараа нь Надад цохиулаад, “ямар ч шалтгаангүй” үхэх боломж олгодог. Бие махбодтой бололт нь Сатаныг шившиглэснээрээ Надад хамгийн их цангинасан гэрчлэл хийдэг; Би махбодоос гарч чаддагаар зогсохгүй, махбод дотор амьдарч чаддаг. Би орон зай, газар зүйн ямар ч хязгаарлалтад өртдөггүй; Миний хувьд ямар ч саад байхгүй бөгөөд бүх зүйл саадгүй явагддаг. Энэ нь Сатаныг хамгийн их шившиглэдэг бөгөөд махбодоос

гарах үедээ Би мөн л Өөрийн махбодоор ажлаа хийдэг, энэ нь Надад ямар ч нөлөө үзүүлдэггүй. Би уул нурууд, гол мөрөн, нуурууд болон орчлон ертөнцийн булан тохой бүрээр болон бүх зүйлийн дээгүүр алхалдаг. Надаас төрсөн боловч Намайг эсэргүүцэхээр боссон бүхнийг илчлэх гэж Би бие махбодтой болсон юм. Хэрэв Би махбод болоогүй бол тэднийг илчлэх ямар ч аргагүй байх байсан (Миний нүүрэн дээр нэг янзаар аяглаж, Миний араар нэг өөр байдаг хүмүүсийг хэлж байна). Хэрэв Би Сүнс хэвээр үлдсэн бол хүмүүс өөрсдийн үзэл дэх Намайг шүтэн мөргөж, Намайг хэлбэр дүрсгүй, хүрч болшгүй Бурхан гэж бодох байсан. Өнөөдөр бие махбодтой болсон минь эгэл жирийн харагддаг, тийм ч өндөр бус тул хүмүүсийн үзлээс нэлээд эсрэг (Миний өндөр болон гадаад төрхийн хувьд) байдаг. Энэ нь Сатаныг хамгийн их шившиглэдэг зүйл бөгөөд хүмүүсийн үзлийн (Сатаны доромжлолын) эсрэг хамгийн хүчтэй хариу юм. Хэрэв Миний гадаад төрх бусад хүн бүрээс өөр байсан бол төвөгтэй байх байсан—хүн бүр өөрсдийн үзлээр дамжуулан Надад шүтэн мөргөж, Намайг ойлгодог болох бөгөөд Надад сайхан гэрчлэл хийж чадахгүй байх байсан. Иймээс Би өнөөгийн дүр төрхөө авсан ба үүнийг ойлгоход огтхон ч бэрх биш. Хүн болгон хүний үзлээс алхан гарч, Сатаны зальхай явуулгад хууртахгүй байх ёстой. Би Өөрийн ажлын хэрэгцээнд нийцүүлэн хожим нь та нарт илүү ихийг нэг нэгээр нь хэлж өгнө.

Өнөөдөр Миний агуу ажил амжилтад хүрч, Миний төлөвлөгөө биелсэн. Би нэгэн сэтгэлээр Надтай санаа нийлэн хамтран ажиллах бүлэг хүмүүсийг олж авсан. Энэ нь Миний хувьд хамгийн алдар суут үе юм. Миний хайртай хөвгүүд (Намайг хайрладаг бүх хүн) Надтай хамт хийх хэрэгтэй бүх зүйлийг Надтай нэг зүрх сэтгэл, нэг оюун санаагаар дуусгаж чаддаг. Энэ бол гайхалтай зүйл. Өнөөдрөөс хойш, Миний тааламжгүй ханддаг хүмүүс Ариун Сүнсний ажилгүй байх болно, өөрөөр хэлбэл, урьд нь Миний хэлсэн зүйлтэй нийцдэггүй хүмүүсийг Би хаяна. Хүмүүс Миний хэлсэнд төгс нийцэх ёстой. Санаж яв! Төгс нийцэх ёстой. Буруугаар бүү ойлго; бүх зүйл Надаас шалтгаалдаг. Хүмүүс ээ, Надтай нөхцөл болзол бүү ярь. Хэрэв Би чамайг тэнцсэн гэж хэлбэл тэр нь өөрчлөгдөшгүй; хэрэв тэнцээгүй гэвэл бүү уруу царайлж, Тэнгэр газрыг буруутга. Энэнь бүгд Миний зохицуулалт юм. Хэн чамайг өөрийгөө үл хүндэтгэ гэж хэлсэн юм бэ? Хэн чамайг ийм ичгүүртэй тэнэг зүйл хий гэсэн юм бэ? Чи юу ч хэлэхгүй байлаа ч гэсэн Надаас үнэнийг нууж чадахгүй. Би бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг Бурхан Өөрөө гэж хэлэхдээ Би хэнд хандаж хэлсэн бэ? Би үүнийг үнэнч шударга бус хүмүүст хэлдэг. Миний араар ийм зүйл хийгээд, ямар ичгүүргүй юм бэ! Та нар Намайг хуурч мэхэлмээр байна уу? Тэгэх нь тийм ч амархан биш! Эндээс үтэр түргэн явцгаа! Тэрслүү хөвгүүд! Чи өөрийгөө хайрладаггүй, өөрийгөө хүндэлдэггүй! Чи өөрийгөө хайхардаггүй атлаа Надаар өөрийгөө хайрлуулахыг хүссээр байна уу? Мартаж үз! Би ийм олиггүй амьтдаас ганцыг ч хүсэхгүй байна. Бүгдээрээ Надаас холд! Энэ чинь Миний нэрэнд хамгийн ноцтой гутамшиг авчирдаг; та нар үүнийг тодорхой харахгүй бол болохгүй. Та нар энэхүү ёрын муу, садар самуун хуучин эрин үед

аливаа бузар буртгаар бохирдохоос өөрсдийгөө хамгаалах ёстой; та нар бүхэлдээ ариун, өө сэвгүй байх ёстой. Өнөөдөр Надтай хамт хаанчлахад тэнцдэг хүмүүс нь ямар ч бузар буртгаар бохирдоогүй хүмүүс байдаг, учир нь Би бол ариун Бурхан Өөрөө бөгөөд Миний нэрийг шившиглэдэг хэнийг ч Би хүсдэггүй. Сатан Намайг туршихын тулд тийм хүмүүсийг явуулдаг бөгөөд тэд бол үнэн хэрэгтээ буцаагаад зодоод явуулах (ёроолгүй нүхэнд хаях) ёстой Сатаны боолууд юм.

Миний гэр бүл ариун агаад өө сэвгүй, Миний сүм эрхэмсэг агаад сүр жавхлантай (Би юу болох, Надад юу байгааг эзэмшсэн хүмүүсийг хэлж байна). Хэн орж, дурарааа үймээн дэгдээж зүрхлэх билээ? Би тэднийг яавч өршөөхгүй. Тэднийг бүрмөсөн устгаж, ихэд шившиглэнэ. Би ухаалгаар үйлддэг. Намайг эсэргүүцэж, Миний нэрийг шившиглэдэг хүмүүсийг Би хутга ч үгүй, буу ч үгүй, хуруугаа ч өргөлгүйгээр бүрмөсөн ялна. Би бол уужим сэтгэлтэй, Сатан ийм хэмжээнд үймээн дэгдээх үед ч гэсэн Би Өөрийн ажлыг нэгэн жигд алхаагаар үргэлжлүүлдэг; түүнд Би анхаарал огт хандуулдаггүй бөгөөд Өөрийн удирдлагын төлөвлөгөөг дуусгаад түүнийг ялна. Энэ бол Миний хүч чадал, Миний мэргэн ухаан, түүнээс ч илүүтэйгээр Миний эцэс төгсгөлгүй алдрын багахан хэсэг юм. Миний нүдээр, Намайг эсэргүүцдэг хүмүүс бол хэдийд ч хүссэнээрээ хөл доороо бяцлан үхүүлж болох хөрс шороонд арзганаж байдаг шавж лугаа адил. Гэвч Би аливааг мэргэн ухаанаар хийдэг. Би Өөрийн ууган хөвгүүдээр үүнийг шийдвэрлүүлнэ; Би яарахгүй байна. Би дэс дараалалтай, эмх цэгцтэй байдлаар, ямар ч алдаагүй яг таг үйлддэг. Надаас төрсөн тэр ууган хөвгүүд Миний юу болохыг эзэмшиж, Миний үйл хэргээс Миний эцэс төгсгөлгүй мэргэн ухааныг харж чаддаг байх ёстой!

92-Р БҮЛЭГ

Хүн бүр Миний үг, үйлдлээс Миний төгс хүчин, Миний мэргэн ухааныг харж чадна. Би хаа ч явсан, Миний ажил тэнд байдаг. Миний мөр зөвхөн Хятадад төдийгүй, дэлхий ертөнцийн бүх улс оронд бий. Гэвч энэ нэрийг эхлээд хүлээн авсан нь зөвхөн өмнө нь дурдсан долоон улс бөгөөд энэ нь Миний ажлын дараалал юм; ойрын ирээдүйд та нар энэ талаар тов тодорхой мэддэг болж, нэгд нэггүй ойлгох болно. Хэрэв Би та нарт одоо хэлбэл үүнээс үүдэн олонх чинь унах болно гэж эмээж байна, учир нь Би та нарын биеийн хэмжээнд тааруулж үг хэлж, Өөрийн дуу хоолойг айлддаг, Миний хийдэг бүхэнд хэний ч ухан ойлгож чадахааргүй эцэс төгсгөлгүй мэргэн ухаан минь бий; цорын ганц арга бол үүнийг та нарт бага багаар хэлж өгөх явдал юм. Үүнийг мэдэж ав! Та нар Миний нүдээр бол үүрд хүүхдүүд хэвээрээ; алхам тутамд чинь Би та нарыг залж чиглүүлж, зааварчлах ёстой. Хүмүүс ээ, зөвхөн Миний удирдамж дор л та нар амьдарч чадна; үүнгүйгээр бол хэн ч цааш амьдарч чадахгүй. Орчлон ертөнц тэр чигтээ Миний гарт байгаа ч ийш тийш яаран гүйж байгааг минь чи хардаггүй. Харин ч эсрэгээрээ Би тайван, аз жаргалтай

байдаг. Хүмүүс Миний төгс хүчинг мэддэггүй, бүгд Миний төлөө сэтгэл түгшинэ—та нар өөрсдийгөө ямар бага мэддэг юм бэ! Та нар Миний өмнө, үнэ цэнгүй аар саар юмаа гайхуулж, өөрсдийгөө бахадсаар байдаг! Би үүнийг эртнээс л нэвт шувт харсан. Бас та нар Миний өмнө заль мэх гаргадаг, муу олиггүй амьтад! Миний гэрээс яг одоо зайл! Би та нар шиг өөдгүй юмнуудыг хүсдэггүй. Та нар шиг олиггүй амьтдыг байлгаж байснаас Миний хаанчлалд хэн ч байгаагүй нь дээр! Чи бахь байдгаараа хооллож, хувцасласаар байгаа ч чам дээр Би аль хэдийн ажиллахаа больсныг чи мэдсэн үү? Гэхдээ чи Сатаны төлөө амьдарч, Сатанд үйлчлэл хийж байгаагаа мэдсэн үү? Гэсэн атлаа чамд Миний өмнө зогсох нүүр байж л байдаг! Үнэхээр ичгүүр сонжуургүй юм!

Урьд нь Би “Агуу гамшиг удахгүй болно; агуу гамшиг Миний гараас аль хэдийн унасан” гэж үргэлж хэлдэг байсан. “Агуу гамшиг” гэж юуг хэлж байна вэ, мөн энэ “унасан” гэдгийг яаж тайлбарлах ёстой вэ? Эдгээр агуу гамшиг нь хүний сүнс, бие, сэтгэлийг гэмтээх зайлахын аргагүй гамшгийг хэлдэг гэж та нар боддог бөгөөд Миний ярьдаг “газар хөдлөлт, өлсгөлөн, тахал” бол эдгээр агуу гамшиг гэж боддог. Гэвч та нар Миний үгийг буруугаар ойлгосноо мэддэггүй. Тэгээд та нар энэ “унасан” гэдэг нь агуу гамшиг эхэлсэн гэх утгатай гэж боддог—инээдтэй юм! Та нар үнэхээр ингэж ойлгодог, та нарын тайлбарыг сонсоод Би үнэхээр уурладаг. Хүмүүсийн илчилж чадаагүй нууц (энэ бол хамгийн далд нууц) бол эрин үеүдийн туршид ч хамгийн ноцтойгоор буруу тайлбарласан нууц бөгөөд хэний ч биечлэн туулаагүй нууц юм (энэ нууц зөвхөн эцсийн өдрүүдэд тохиох учиртай тул зөвхөн сүүлийн эрин үеийн хүн л харж чадах ч үүнийг танихгүй), Би үүнийг хамгаас чанд битүүмжилсэн учир хүн үүнд нэвтэрч огт чадахгүй (бүр үүний хамгийн өчүүхэн хэсгийг ч харж чадахгүй). Одоо Миний ажил энэ үе шат хүртэл явагдсан тул Өөрийн ажлын хэрэгцээний дагуу Би та нарыг гэгээрүүлнэ; эс тэгвэл хүмүүс яагаад ч ойлгохгүй. Одоо Би нөхөрлөж эхэлнэ; хүн бүр анхаарал хандуулах ёстой, учир нь Миний ууган хөвгүүдийг оролцуулаад анхааралгүй байсан хэн ч бай, Миний шүүлтийг туулна, бүр ноцтой тохиолдолд тэд Миний гарт цохиулан унана (тэдний сүнс, сэтгэл, биеийг авна гэсэн үг). Агуу гамшгийг Миний хаанчлалын захиргааны зарлиг нэг бүртэй холбоотойгоор ярьдаг бөгөөд Миний захиргааны зарлигийн нэг бүр нь агуу гамшгийн нэг хэсэг юм. (Миний захиргааны зарлиг та нарт бүхэлдээ ил болоогүй ч үүнд бүү санаа зов, бүү сэтгэл түгш; хэтэрхий эрт мэдвэл та нарт ашиг тус багатай зарим зүйл бий. Үүнийг санаж яв! Би бол ухаалаг Бурхан.) Тэгвэл нөгөө хэсэг нь юу вэ? Агуу гамшиг нь Миний захиргааны зарлиг, Миний уур хилэн гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Агуу гамшиг тохиолдох цаг үе нь бас Би уурандаа шатаж, Өөрийн захиргааны зарлигийг хэрэгжүүлж эхлэх цаг үе байх болно. Энд Би Өөрийн ууган хөвгүүдэд хэлье: Та нар үүнээс болоод яавч доройтох ёсгүй. Бүх зүйл, бүх юмыг Би урьдчилан тогтоодог гэдгийг чи мартаа юу? Миний хүү, юунаас ч бүү ай! Би чамайг хамгаалах нь лавтай; чи Надтай хамт үүрд сайн ерөөл эдэлж, Надтай мөнхөд хамт байх болно. Чи Миний хайртай хүн тул Би чамайг орхихгүй. Би мунхаг зүйл

хийдэггүй, гэхдээ хэрвээ Би ийм хүндрэл бэрхшээлтэйгээр дуусгасан зүйлээ тастан хаявал Өөртөө л гай чирч байгаа хэрэг болох бус уу? Чамайг зүрх сэтгэлдээ юу боддогийг Би мэднэ. Чи санав уу? Надаар өөр юу гэж хэлүүлмээр байна? Би агуу гамшгийн тухай илүү их ярья. Агуу гамшиг болох цаг үе бол хамгийн аймшигтай цаг үе байх бөгөөд хүний муу муухайг дээд зэргээр илчилнэ. Миний нүүр царайн гэрэлд бүх төрлийн чөтгөрлөг дүр төрх илчлэгдэн, нууж, халхлах газаргүй, бүрэн ил болно. Агуу гамшгийн үр нөлөө нь Миний сонгоогүй, урьдчилан тогтоогоогүй бүх хүнийг Миний өмнө сөгдүүлж, уйлж, шүдээ хавиран Надаас уучлал гуйхад хүргэх юм. Энэ бол Сатаныг шүүх Миний шүүлт, Миний хилэнт шүүлт. Одоо Би энэ ажлыг хийж байгаа бөгөөд чадвартай мэт дүр эсгэж, худал үгээр замаа засах гэсэн хэсэг хүн байж магадгүй; ингэх тусам нь Сатан тэдэн дээр улам их ажиллаж, улмаар анхны дүр төрх нь илчлэгдэх тэр цэгт хүрэх болно.

Би Өөрийн ажлыг хийх гэж яарахгүй байна, Би хүн бүрийг Өөрөө зохион байгуулж (энэ нь тэднийг элэг доог болгож, агуу улаан лууны үр удам гэдгийг нь нотолдог, Би тэдэнд анхаарал хандуулдаггүй учир “зохион байгуулдаг” гэх үгийг ашиглах нь хэтийдсэн хэрэг биш), бүх үйл хэргийг Өөрөө гүйцэтгэдэг. Миний хувьд бүх зүйл амжилттай болдог, энэ бол аюулгүй, баттай амжилт юм; Миний хийдэг бүхэн алхам алхмаар аль хэдийн зохицуулагдсан. Би та нарт Өөрийн хүсэл, Өөрийн ачааг бага багаар хэлдэг. Энэ үеэс эхлэн Миний үг бүх улс үндэстэн, бүх ард түмэнд харагдаж эхэлнэ. Миний ууган хөвгүүд аль хэдийн бүрэн төгс болгуулсан учраас (Миний үг Миний хөвгүүд, Миний ардуудад голлон анхаардаг) Миний ажилладаг арга барил дахин өөрчлөгдөж эхэлсэн. Үүнийг тодорхой харж байна уу? Сүүлийн хэдэн өдөрт та нар Миний ярианы өнгийг мэдэрсэн үү? Би Өөрийн ууган хөвгүүдийг замын алхам бүрд тайтгаруулдаг боловч одоогоос эхлэн (Миний ууган хөвгүүд аль хэдийн бүрэн төгс болсон тул) гартаа хутга барьж байна (“хутга” гэдэг нь “хамгийн хатуу үг” гэсэн үг юм). Хоромхон зуур тааламжгүй харагдсан хэнийг ч болов (энэ нь урьдчилан тогтоогдож, сонгогдоогүй хүмүүсийг хэлдэг, иймээс зөрчилдсөн зүйл байхгүй) Надад үйлчлэл үзүүлж байна уу, эсвэл өөр зүйл байна уу хамаагүй, Би даруйхан хаях болно. Би бол төгс хүчит Бурхан, Би бүх хүнээр Өөртөө үйлчлэл хийлгэж чадна. Би тийм хүмүүсээс хагацахдаа огт дургүйцэхгүй; хэрвээ Би тэднийг хүсдэггүй гэж хэлбэл хүсдэггүй л гэсэн үг. Одоо энэ цаг ирсэн учир Өөрийн минь сэтгэлд нийцдэггүй хүнийг харах л юм бол Би тэднийг шинжлэх ч үгүйгээр даруй хаяна, учир нь Би бол хэлсэндээ хүрдэг Бурхан билээ. Надад үйлчлэхээр Надаар урьдчилан тогтоогдсон хүмүүсийн хувьд гэвэл, чи хэчнээн сайн байлаа ч гэсэн, Намайг эсэргүүцэх ямар нэг зүйл хийсэн ч бай үгүй ч бай, хэрвээ Надад таалагдахгүй л бол Би шууд хөөж явуулна. Ирээдүйн гай бэрхшээлээс Би айдаггүй. Надад Өөрийн минь захиргааны зарлиг бий, Би үгэндээ хүрдэг бөгөөд Миний үг биелэх болно. Би Сатаныг үлдээнэ гэж үү? Намайг сонсоцгоо, хүмүүс ээ! Та нар айх хэрэггүй; Намайг яв гэж хэлэхэд чи явах ёстой. Надад бүү шалтаг тооч; чамд хэлэх үг Надад үгүй! Учир нь Би ихэд тэвчсэн, тэгээд

ч Миний захиргааны зарлигийг хэрэгжүүлэх цаг ирж, та нарын эцсийн өдөр ч бас ирээд байна. Олон мянган жил та нар эх захаа алдаж, аливааг дандаа толгой мэдэн, дураараа хийдэг байсан ч Би үргэлж хүлээцтэй байсан (Би уужим сэтгэлтэй бөгөөд чиний завхралыг тодорхой хэмжээнд зөвшөөрдөг). Гэвч одоо Миний өршөөл төгсгөлдөө ирсэн бөгөөд та нарыг эзэмдэж, гал болон хүхэрт нууранд хаях цаг ирлээ. Үтэр түргэн замаас минь зайл. Би Өөрийн шүүлтийг албан ёсоор хэрэгжүүлж, Өөрийн уур хилэнг гаргаж эхэллээ.

Дэлхий ертөнцийн бүх улс үндэстэн, бүх газар нутагт газар хөдлөл, өлсгөлөн, тахал, элдэв янзын гамшиг ойр ойрхон тохиолдож байна. Намайг бүх улс үндэстэн, бүх газар нутагт агуу ажлаа хийх үед эдгээр гамшиг дэлхий ертөнцийг бүтээснээс хойш ямар ч цаг үед болж байснаас илүү ширүүн байх болно. Энэ бол бүх хүнийг шүүх Миний шүүлтийн эхлэл, гэхдээ Миний хөвгүүд тайван байж болно; та нарт ямар ч гамшиг тохиолдохгүй, мөн Би та нарыг хамгаална. (Та нар дараа нь махбод бус, биед амьдрах учир ямар ч гамшгийн зовлон шаналлыг туулахгүй гэсэн үг.) Та нар зүгээр л Надтай хамт хаан болж хаанчлан, бүх улс үндэстэн, бүх ард түмнийг шүүж, орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаарт Надтай хамт үүрд сайн ерөөл эдэлнэ. Эдгээр үг бүгд хэрэгжиж, нүдний чинь өмнө удахгүй биелнэ. Би ганц ч цаг, ганц ч өдөр хойшлуулалгүй, аливааг асар хурдан хийдэг. Бүү санаа зов, бүү түгш; чамд Миний өгсөн ерөөлийг өөр хэн ч булаан авч чадахгүй—энэ бол Миний захиргааны зарлиг юм. Бүх хүн Миний үйл хэргээс үүдэн Надад дуулгавартай байх болно; тэд тасралтгүй уухайлаад зогсохгүй, баярласандаа эцэс төгсгөлгүй дэвхцэх болно.

93-Р БҮЛЭГ

Хүний нүдний өмнө бодит баримтууд биелж, бүх зүйл аль хэдийн биелсэн; Миний ажлын явц түргэсэж, харвасан пуужин шиг өндөрт хөөрч байна. Хэн ч ингэнэ гэж таамаглаж байгаагүй. Аливаа зүйл болж өнгөрсний дараа л та нар Миний үгийн жинхэнэ утгыг ойлгоно. Агуу улаан лууны үр сад ч ялгаагүй, Миний гайхалтай үйл хэргийг тэдэнд харуулах ёстой. Одоо чи Миний үйл хэргийг хараад Миний талаар бат итгэлтэй болсон тул Би чамайг хаяхгүй гэж бүү бод—энэ тийм энгийн биш! Би хэлсэн үг, шийдсэн үйл хэргээ гарцаагүй биелүүлэх бөгөөд тэдгээр нь Над руу хоосон буцаж ирэхгүй. Миний ууган хөвгүүд болсон цөөнхөөс гадна Миний ардууд болсон тоотой хэдэн хүн Хятадад бий. Иймээс та нар (Намайг хамгийн аймшигтайгаар хяхаж хавчсан агуу улаан лууны үр сад) асар их найдвар тээх ёсгүй, Миний ажил (дэлхийг бүтээсэн цагаас хойш) Миний ууган хөвгүүд болон Хятадын чанад дахь хэдэн улс оронд төвлөрч байсан гэдгийг өнөөдөр Би та нарт тодорхой хэлье. Ийм учир, Миний ууган хөвгүүд өсөж том болсон цагт Миний хүсэл биелэх болно. (Миний ууган хөвгүүд өсөж том болмогц бүх зүйл хийгдэнэ, учир нь ирээдүйн

даалгаврыг тэдэнд өгсөн.) Одоо Би агуу улаан лууг шившиглэхийн тулд л энэ хүмүүст Өөрийн гайхалтай үйл хэргийн нэг хэсгийг харуулж байна. Энэ хүмүүс үүнээс таашаал авч ерөөсөө чадахгүй боловч Надад үйлчлэл үзүүлж байгаадаа л баярлах болно. Надад захиргааны зарлиг байгааг хэн ч зөрчиж зүрхлэхгүй тул тэдэнд өөр ямар ч сонголт үгүй.

Одоо Би харийнхны ирэхтэй холбоотой зарим нөхцөл байдлын тухай нөхөрлөе, ингэснээр та нар энэ талаар урьдаас мэдэж авч, Миний нэрийг гэрчлэхийн тулд бүхнийг зохих ёсоор бэлдэж, тэдний дээр зогсон, тэднийг захирна. (Тэдний дундах хамгийн агуу нь та нарын дундах хамгийн өчүүхэн нь учир Би “тэдний дээр зогсон, тэднийг захир” гэж хэлдэг.) Энэ хүмүүс бүгд Ариун Сүнсний илчлэлийг олж авсан бөгөөд ирээдүйд тэд урьдчилсан зохицуулсан мэт Хятад руу бүгд бөөгнөрөн орж ирнэ. Агуу улаан луу цочирдож, эсэргүүцэхийн тулд чадах бүхнээ хийх ч нэг зүйлийг санаж яв! Миний удирдлагын төлөвлөгөө бүрмөсөн биелсэн бөгөөд Миний алхамд хүн ч, юу ч саад хийж зүрхлэхгүй. Би тэдэнд цаг ямагт илчлэл өгч, тэд Ариун Сүнсний удирдамжийг даган үйлддэг. Миний дотор бүгд чөлөөлөгдөж, эрх чөлөөтэй болдог тул тэд агуу улаан луунд яавч хүлэгдэхгүй. Би бүх зүйлийг зохих ёсоор зохицуулсан бөгөөд тэднийг хариулах бэлтгэл ажлыг базаахыг чинь хүлээж байна. Би байнга ингэж хэлдэг байсан ч олонх чинь одоо ч хагас хугас итгэдэг. Одоо яаж байна? Та нар гайхширч орхиж, тийм биз?

Эдгээр зүйл бүгд хоёрдогч; гол зүйл гэвэл та нар бүх бэлтгэл ажлыг аль болох хурдан базаах явдал юм. Бүү түгш. Ажлыг хийдэг Нэгэн нь Би бөгөөд цаг нь ирэхэд Би Өөрийн ажлыг Өөрөө хийх болно. Би агуу улаан лууг хэдэн хэсэг болгон няц дарсан. Өөрөөр хэлбэл, Миний Сүнс Миний ууган хөвгүүдээс бусад бүх хүнээс холдсон (хэн нь агуу улаан лууны үр сад болохыг илчлэхэд одоо амархан болж байна). Энэ хүмүүс Надад үйлчлэл үзүүлж дууссан бөгөөд Би тэднийг ёроолгүй нүх рүү буцаана. (Энэ нь Би тэдний хэнийг ч ашиглахгүй гэсэн үг. Одоогоос эхлээд Миний ууган хөвгүүд бүрэн илчлэгдэнэ, Миний хажууд байгаа, Надаар ашиглуулахад тохирох хүмүүс Миний ууган хөвгүүд байх болно). Миний ууган хөвгүүд ээ, та нар Миний хайрласан ерөөлийг албан ёсоор эдэлж (учир нь Миний жигшдэг бүх хүн жинхэнэ дүр төрхөө харуулсан), үүнээс хойш Намайг эсэргүүцэх явдал та нарын дунд дахин тохиолдохгүй. Та нар Надад үнэхээр 100 хувь бат итгэлтэй байдаг. (Өнөөдөр л энэ бүрэн биелсэн, Би энэ цагийг урьдчилан товлосон.) Та нарын зүрх сэтгэл, оюун ухаандаа тээдэг зүйл чинь Намайг гэх эцэс төгсгөлгүй хайр, хүндлэл бөгөөд та нар цаг ямагт Намайг магтаж, Надад алдар суу өгдөг. Та нар үнэхээр Миний хайрын халамж, хамгаалалтад, гурав дахь тэнгэрт амьдарч байна. Ямар зүйрлэшгүй жаргал, баяр баясал вэ! Энэ бол хүмүүс төсөөлөхийн аргагүй өөр нэгэн ертөнц—жинхэнэ сүнсний ертөнц юм!

Бүх гамшиг ар араасаа тохиож, нэг бүр нь өмнөхөөсөө ширүүсэж, нөхцөл байдал өдрөөс өдөрт улам түгшүүртэй болж байна. Энэ бол ердөө гамшгийн эхлэл; дараа нь тохиох бүр ширүүн гамшгийг хүн төсөөлж ч чадахгүй. Миний хөвгүүд

тэднийг зохицуулаг; энэ бол Миний аль эрт зохицуулсан Миний захиргааны зарлиг. Хүний урьд өмнө нь хэзээ ч харж байгаагүй тэмдэг, гайхамшгууд Надаас гарч, нэг нэгээрээ бүх хүнд (Миний хаанчлалын бүх хүн гэсэн үг) үзэгдэж байна. Гэвч энэ бол ойрын ирээдүйд болох зүйл. Бүү сэтгэл түгш. Хаанчлалд орох энэ явдлыг хүн бүр ярьцгааж байсан—тэгвэл хаанчлалд орох байдал нь ямар байх вэ? Бас хаанчлал гэж юу вэ? Энэ нь бодит хот уу? Та нар буруугаар ойлгодог. Хаанчлал газар дээр ч байхгүй, бодит тэнгэр дээр ч байхгүй, харин хүний харж, хүрч чадахгүй сүнсний ертөнц юм. Миний нэрийг хүлээн аваад Надаар бүрэн төгс болгуулж, Миний ерөөлийг эдэлдэг хүмүүс л үүнд орж чадна. Урьд нь үргэлж дурдаж байсан сүнсний ертөнц гэдэг бол хаанчлалын гадаргуу юм. Хаанчлалд үнэхээр орох нь харин амаргүй хэрэг. Үүнд орох хүмүүс Миний амлалтыг авах ёстой, мөн Миний урьдчилан тогтоож, Өөрөө сонгосон хүмүүс байх ёстой. Иймээс сүнсний ертөнц гэдэг нь хүмүүс дурааараа ирж, очиж болох газар биш. Энэ талаарх хүмүүсийн ойлголт маш өнгөцхөн байсан бөгөөд тэр чигээрээ хүний үзлээс л бүрддэг. Зөвхөн хаанчлалд орсон хүмүүс л ерөөл эдэлж чадах учир хүн эдгээр ерөөлийг эдэлж чадахгүйгээр үл барам, харж ч чадахгүй. Энэ бол Миний захиргааны зарлигийн сүүлчийнх нь юм.

94-Р БҮЛЭГ

Сион руу Би Өөрийн ууган хөвгүүдтэй хамт буцдаг гэх үгийн жинхэнэ утгыг та нар үнэхээр ойлгож байна уу? Би та нарт хэдхэн удаа сануулж байсанчлан, Би та нарыг хурдан өсөж том болоод, Надтай хамт хаанчлаасай гэж хүсдэг. Та нар санаж байна уу? Эдгээр нь бүгд бие махбодтой болсонтой минь шууд холбоотой юм: Би Өөртэйгөө нэгэн адил оюун санаатай бүлэг хүнийг махбодоор дамжуулж олж авахын тулд Сионоос дэлхий ертөнцөд махбод болж ирсэн бөгөөд ингэснээр бид Сион руу буцна. Энэ нь бид махбодоос анхны биедээ буцах хэрэгтэй л гэсэн үг юм. Энэ бол “Сион руу буцах” гэдгийн жинхэнэ утга учир билээ. Энэ нь бас Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний жинхэнэ утга учир, гол хэсэг гэдгээр зогсохгүй Миний удирдлагын төлөвлөгөөний хэн ч саад болж чадахгүй, бас нэн даруй биелэх хамгийн чухал хэсэг юм. Хүн махан биед байхдаа хүний үзэл, сэтгэлгээгээ хэзээ ч хаяж чадахгүй, тэр ч байтугай газрын агаар, тоосыг хаяж бүр ч чадахгүй, үргэлж шавар байх болно; хүн биед байхдаа л ерөөл эдлэх эрхтэй болно. Ерөөл гэж юу вэ? Та нар санаж байна уу? Махан биед, ерөөлд санаа тавих боломжгүй учраас махан биеэс биед хүрэх зам бол ууган хүү бүрийн дагах ёстой зам билээ. Махан биед та нар агуу улаан лууд дарлагдаж, хавчигддаг (та нарт ямар ч хүч чадал байхгүй, алдар суу олоогүй учраас тэр юм) боловч биед их өөр байх бөгөөд та нар бахархалтай, баяр хөөртэй байх болно. Дарлуулах өдөр бүрмөсөн эцэс болж, та нар үүрд суллагдаж, чөлөөтэй болно. Ийм маягаар л Би та нарт Өөрийн юу болох,

Өөрт минь юу байгаагаа нэгтгэж чадна. Эс бөгөөс, та нарт Миний хэв чанар л байх болно. Хүн өөр нэг хүнийг гаднаа хэчнээн дуурайлаа ч, яг адилхан болж чадахгүй. Зөвхөн ариун сүнслэг биед л (биеийг хэлж байна) бид яг адилхан байж чадна (энэ нь адилхан хэв чанартай, адилхан оршихуйтай, эзэмшсэн зүйл нь адилхан, санаа нэгтэй, нэгдмэл, салшгүй, салангид бус байж чадахыг хэлдэг, учир нь энэ бүгд ариун сүнслэг бие юм).

Яагаад одоо та нар ертөнцийг үзэн ядаж, идэх, өмсөх гэх мэт бүхий л төрлийн иймэрхүү яршигтай зүйлд ой гутаж эхлэн, тэр ч байтугай тэдгээрээс ангижирна гэхээс байж ядаж байгаа вэ? Энэ бол та нар сүнсний ертөнц (бие) рүү орохын тэмдэг юм. Та нарт бүгдэд нь ийм совин байгаа (тэдгээр нь хэмжээгээрээ ялгаатай ч гэлээ). Би Өөрийн хамгийн чухал алхамд бүгдийг нь үйлчлүүлэхээр өөр өөр хүн, үйл явдал, юмсыг ашиглах бөгөөд тэдгээр нь бүгд Надад үйлчлэл үзүүлэх болно. Би тэгэх ёстой. (Цаг нь хараахан болоогүй тул Би үүнийг мэдээж махбодод байхдаа гүйцэлдүүлж чадахгүй, Миний Сүнс л Өөрөө энэ ажлыг хийж чадна.) Энэ бол бүхий л орчлон ертөнцийн үйлчлэх эцсийн өчүүхэн жижиг чиг үүрэг юм. Хүн бүр Намайг магтаж, Намайг баяр хөөртэйгөөр хүлээн авна. Миний агуу ажил гүйцэлдлээ. Миний гараас долоон аягатай гамшиг асгарч, долоон аянга нүргэлж, долоон бүрээ дуугарч, долоон лац орчлон ертөнцөд, бүх улс үндэстэн, бүх ард түмэнд, уул нурууд, гол мөрөнд, бүх зүйлд нээгддэг. Долоон аягатай гамшиг гэж юу вэ? Тэдгээрийн бай нь яг юу вэ? Би яагаад тэдгээрийг гараас минь асгарна гэж хэлдэг вэ? Хүн бүр бүрэн үнэмшиж, хүн бүр гүйцэд ойлготол урт удаан хугацаа өнгөрөх болно. Би одоо та нарт хэллээ ч, та нар ердөө багахан хэсгийг л ойлгоно. Хүний төсөөллөөр бол долоон аягатай гамшиг дэлхийн бүх улс орон, ард түмэнд чиглэсэн байдаг боловч үнэн хэрэгтээ тийм биш. Энэхүү “долоон аягатай гамшиг” гэдгээр диавол Сатаны нөлөө, агуу улаан лууны хуйвалдааныг хэлдэг (Би Өөртөө үйлчлэл үзүүлэхээр ашигладаг зүйлс). Тэр үед, Би хөвгүүд, ардуудыг гэсгээхээр Сатан болон агуу улаан лууг чөлөөлж, улмаар хэн нь хөвгүүд, хэн нь ардууд болох нь илчлэгдэнэ. Мэхлэгдсэн хүмүүс нь Миний урьдчилан тогтоосон бай биш, харин Миний ууган хөвгүүд тэр үед, Надтай хамт хаанчилж байх болно. Ийм маягаар, Би хөвгүүд болон ардуудыг бүрэн төгс болгоно. Долоон аягатай гамшгийг асгах нь бүх улс үндэстэн, ард түмэнд нөлөөлөхгүй, зөвхөн Миний хөвгүүд, ардуудад нөлөөлнө. Ерөөл амар олддоггүй; бүрэн төлөөс төлөх ёстой. Хөвгүүд, ардууд өсөж том болоход долоон аягатай гамшиг бүрмөсөн үгүй болж, цаашид оршихгүй. Долоон аянга нүргэлэх гэдэг нь юу вэ? Үүнийг ойлгоход хэцүү биш. Би болон Миний ууган хөвгүүд бие болох мөчид долоон аянга нүргэлнэ. Энэ нь тэнгэр, газар орвонгоороо эргэсэн мэт бүхий л орчлонг доргионо. Хүн бүр үүнийг мэднэ, хэн ч мэдэлгүй хоцрохгүй. Тэр цагт Би болон Миний ууган хөвгүүд алдар суугаар хамт байж, ажлын дараагийн алхмыг эхэлнэ. Долоон аянгын нүргээнээс болж, олон хүн өвдөг сөгдөн, өршөөл, уучлал эрнэ. Гэвч, Нигүүлслийн эрин үе байхаа болино: Уур хилэнгийн цаг үе байх болно. Ёрын мууг үйлддэг бүх хүний хувьд, (Миний сонгосон хүмүүсээс

бусад завхайрдаг, бохир мөнгөөр наймаацдаг, эсрэг хүйстэнтэйгээ барьдаг зааг хязгаар нь бүрхэг, Миний удирдлагад саад, хор учруулдаг, эсвэл сүнслэг асуудлыг ойлгодоггүй, муу сүнсэнд эзэмдүүлсэн хүмүүс) нэгийг нь ч зүгээр өнгөрөөж, өршөөлгүй, бүгдийг нь Үхэгсдийн оронд унагааж, тэндээ тэд үүрд мөхнө! “Долоон бүрээ дуугарах” гэдэг асар том, тааламжгүй орчныг хэлж байгаа юм биш, дэлхий ертөнцөд ямарваа тунхаглал хийхийг ч хэлдэг юм биш; эдгээр нь бүхэлдээ хүний үзэл юм. “Долоон бүрээ” гэдгээр Миний хилэнт айлдварыг хэлдэг. Миний дуу хоолой (сүр жавхлант шүүлт болон уур хилэнт шүүлт) гарахад долоон бүрээ дуугардаг. (Яг одоо, Миний гэрийн нөхцөлд энэ хамгийн ноцтой нь бөгөөд хэн ч үүнээс зугтаж чадахгүй.) Үхэгсдийн орон болон там дахь бүх чөтгөр том ч бай, жижиг ч бай гараараа толгойгоо бариад, зүг бүрд зугтан, ичээд, нүүр хийх газаргүйгээр уйлж, шүдээ хавирна. Одоохондоо долоон бүрээ дуугарч эхлээгүй байгаа боловч, хэний ч зугтаж чадахгүй, бүгдийнх нь туулах ёстой, Миний дүрэлзсэн уур хилэн, бас Миний хамгийн хатуу шүүлт гарч ирсэн билээ. Энэ удаад илчлэгдсэн зүйл бол долоон лацны агуулга биш юм. Долоон лац бол та нарын ирээдүйд эдлэх ерөөл мөн. “Нээх” гэдэг нь ердөө л та нарт мэдэгдэхийг хэлж байгаа боловч та нар эдгээр ерөөлийг хараахан эдлээгүй байна. Та нар эдгээр ерөөлийг үнэхээр эдлэх үедээ долоон лацны агуулгыг мэдэх болно. Одоо та нар хараахан бүрэн төгс болоогүй нэг хэсэгт нь л гар хүрч байна. Би алхам бүрийн талаар ирээдүйн ажлын үеэр гарч ирэхэд нь л хэлж өгч чадна, тиймээс та нар үүнийг биечлэн туулж, зүйрлэшгүй алдар сууг мэдэрч, эцэс төгсгөлгүй хөөрч баярласан байдалтай оршино.

Ууган хөвгүүдийн ерөөлийг эдэлж чадна гэдэг амар зүйл ч биш, ердийн хүний хүрч чаддаг зүйл ч биш. Би Өөрийн ууган хөвгүүдэд хатуу шаардлага тавих ёстой гэдгээ дахин нэг онцолж, илүү хүч нэмж хэлье. Эс бөгөөс, тэд Миний нэрийг алдаршуулж чадахгүй. Би дэлхий ертөнцөд муу нэртэй хэнийг ч болов тууштай голно, садар самуун хүмүүсийг бүр ч их голно. (Тэд Бурханы ардууд болох хувьгүй—үүнийг Би ихэд онцолдог.) Өнгөрсөнд хийсэн зүйл чинь элэрч, баларсан гэж бүү бод—тийм сайхан зүйл байж яаж болох юм бэ! Ууган хөвгүүний байр суурийг олох тийм энгийн хэрэг үү? Миний эсрэг байдаг, махбодод байгаа Намайг таньдаггүй, хүслээ биелүүлэхэд минь саад болдог, Намайг хяхан хавчдаг хэнийг ч Би адилхан голдог—Би ийм л хатуу (учир нь Би Өөрийн хүч чадлыг бүрэн эргүүлж авсан)! Эцэст нь, амьдралд нь бүтэлгүйтэл гэж байгаагүй хэнийг ч болов Би адилхан голдог. Жаахан зовлон байсан ч бай, Над шиг зовлон зүдүүрээ даван гарсан хүмүүсийг Би хүсдэг. Тэгээгүй бол, тийм хүмүүсийг Би өшиглөн гаргана. Миний ууган хөвгүүд болохыг хүсэж, Миний өмнө өөрсдийгөө гайхуулж, бүү ичгүүргүй аашил. Надаас хурдан холд! Өмнө нь чи Миний тааллыг олж авах гэж жижиг сажиг асуудлаа Надад хэлж байсан! Энэ бол сохор байгаа хэрэг! Хэнд ч хэрэггүй олиггүй амьтан минь, чамайг үзэн яддагийг минь мэддэггүй юм уу? Намайг далд үйл хэргийг чинь мэддэггүй гэж бодоо юу? Чи ахин дахин нуугдах юм! Чи

диавол царайгаа харуулчихсан гэдгээ мэдэхгүй байна уу? Энийг чинь хүмүүс харж чаддаггүй байлаа ч, Намайг бас харж чадахгүй гэж чи бодоо юу? Надад үйлчлэл үзүүлдэг хүмүүс сайн хүмүүс биш, хэдэн хэнд ч хэрэггүй олиггүй амьтад. Би тэдэнтэй харьцах ёстой. Би тэднийг ёроолгүй нүхэнд хаяад, шатаах болно!

Чи сүсэг бишрэлгүй байдлаар ярьж, итгэл үнэмшилгүй үйлдэж, бусадтай зүй ёсоор хамтран ажилладаггүй; тийм хүн хаан болохыг хүссээр байна—чи зүүдлээгүй биз? Чи солиороогүй биз? Өөрийнхөө юу болохыг харахгүй байна уу? Чи бол хэнд ч хэрэггүй, олиггүй амьтан! Ийм хүний хэрэг гэж байна уу? Миний нүднээс бушуу далд ор! Хүн бүр Миний хэлж байгааг тодорхой ойлгож, үгнээс минь онгод авч, Миний төгс хүчийг хүлээн зөвшөөрч, Миний мэргэн ухааныг мэдэх хэрэгтэй. Ариун сүнслэг бие илэрсэн гэж олонтоо хэлсэн. Эцсийн эцэст, та нар ариун сүнслэг бие илэрсэн гэж хэлэх үү, үгүй юу? Миний хэлдэг зүйл хоосон яриа юу? Ариун сүнслэг бие гэж юу вэ? Ямар нөхцөлд ариун сүнслэг бие оршин байдаг вэ? Хүмүүст энэ нь төсөөлшгүй, ойлгогдохын аргагүй байдаг. Би та нарт хэлье: Би бол өө сэвгүй, Миний дотор бүгд нээлттэй, бүх зүйл чөлөөлөгдсөн байдаг (учир нь Би ухаалгаар үйлдэж, чөлөөтэй ярьдаг). Миний үйлдэлд ичгүүртэй зүйл огт үгүй, бүхнийг гэрэлд хийдэг тул хүн бүр бүрэн үнэмшиж болно. Түүнчлэн, Миний эсрэг ашиглах зүйлийг хэн ч өөрөөсөө олж чадахгүй. Энэ бол “ариун сүнслэг бие” гэдгийн “ариун” гэдгийн тайлбар юм. Тиймээс, Би ичгүүртэй зүйл хийдэг хэнийг ч хүсдэггүй гэдгээ удаа дараа онцолсон. Энэ бол Миний захиргааны зарлигийн нэг зүйл, бас Миний зан чанарын нэг хэсэг юм. “Сүнслэг бие” гэдэг нь Миний айлдварыг хэлдэг. Миний хэлдэг зүйлд үргэлж зорилго, мэргэн ухаан байдаг ч, үгийг минь хянаж болохгүй. (Би хүссэн зүйлээ хэлдэг, Миний Сүнс дуу хоолойгоо айлдаж, Миний үнэн бие ярьж байгаа.) Миний хэлдэг зүйл чөлөөтэй гардаг бөгөөд хүмүүсийн үзэлтэй нийцэхгүй байх үед хүмүүсийг илчлэх цаг нь тэр байх болно. Энэ бол Миний зүй ёсны зохицуулалт юм. Тиймээс, Миний үнэн бие ярьж, үйлдэх бүрд Сатаны гол чанарыг илчлэх сайхан боломж үргэлж болдог. Миний үнэн бие тослогдох үед ариун сүнслэг бие гарч ирдэг. Цаашид, ариун сүнслэг бие гэдэг нь биеийг хэлэх бөгөөд энэ утгад хоёр тал бий. Нэг талын утга нь өнөө үед, нөгөө талын утга нь ирээдүйд байдаг. Гэхдээ ирээдүйд ариун сүнслэг бие одоогийнхоос их өөр, тэнгэр газар шиг ялгаатай байна. Хэн ч үүнийг ухаж ойлгож чадахгүй бөгөөд Би үүнийг та нарт биечлэн илчлэх ёстой болно.

95-Р БҮЛЭГ

Хүмүүс юм болгоныг асар энгийнээр төсөөлдөг ч үнэн хэрэгтээ тийм байдаггүй. Бүх зүйлийн дотор далд нууцууд, мөн Миний мэргэн ухаан, Миний зохицуулалт агуулагдаж байдаг. Ямар ч нарийн ширийнийг орхилгүй, бүгдийг Би зохицуулдаг. Агуу өдрийн шүүлт Намайг чин сэтгэлээсээ хайрладаггүй хүмүүс дээр бууж (агуу

өдрийн шүүлт нь энэ нэрийг хүлээн авсан бүх хүнд чиглэсэн гэдгийг сана), тэднийг уйлж, шүдээ хавирахад хүргэдэг. Энэхүү уйлах чимээ Үхэгсдийн орон, бас тамаас гардаг; энэ нь хүмүүс бус, чөтгөрүүд уйлж буй хэрэг юм. Миний шүүлт ийм уйлааныг авчирч, Миний удирдлагын төлөвлөгөөний эцсийн авралыг хүмүүст авчирдаг. Би зарим хүнд бага зэрэг найдлага тавьдаг байлаа. Гэвч одоо харахад, Би энэ хүмүүсийг нэг нэгээр нь хаях ёстой, учир нь Миний ажил энэ үе шатанд хүрсэн бөгөөд үүнийг хэн ч өөрчилж чадахгүй. Миний ууган хөвгүүд, эсвэл Миний ардууд биш бүх хүнийг хаяж, Надаас холдуулах ёстой! Хятадад Миний ууган хөвгүүд болон Миний ардуудаас бусад бүх хүн агуу улаан лууны үр сад бөгөөд хаягдах болно гэдгийг та нар ойлгох ёстой. Эцсийн эцэст Хятад бол Миний хараасан үндэстэн бөгөөд тэнд байгаа Миний цөөхөн ардууд бол Миний ирээдүйн ажилд үйлчлэл үзүүлдгээс цаашгүй гэдгийг та нар бүгд ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл, Миний ууган хөвгүүдээс өөр хэн ч байхгүй, бүгд мөхнө. Би үйл хэргээ хэтийдүүлсэн гэж бүү бод—энэ бол Миний захиргааны зарлиг. Миний хараалд өртдөг хүмүүс бол Миний үзэн ядалтын бай, үүнийг өөрчлөх боломжгүй. Би алдаа гаргадаггүй; хэрэв дургүйг минь хүргэсэн хүн байгааг харвал Би өшиглөн явуулах болно; энэ нь, чи бол Надад хараагдсан бөгөөд агуу улаан лууны үр удам гэдгийн хангалттай нотолгоо мөн. Та нарт дахин нэг сануулъя—Хятадад зөвхөн Миний ууган хөвгүүд л бий (үйлчлэл үзүүлдэг Миний ардуудаас гадна), энэ Миний захиргааны зарлиг юм. Гэвч Миний ууган хөвгүүд маш цөөхөн бөгөөд бүгдийг нь Би урьдчилан тогтоосон—Би Өөрийн хийдэг зүйл юу болохыг мэднэ. Надад Өөрийн захиргааны зарлиг, бас уур хилэн гэж бий тул Би чиний сөрөг байдлаас айдаггүй, бас чамайг ар нуруунаас минь хутгалах вий гэхээс айдаггүй. Өөрөөр хэлбэл, Би бүх зүйлийг аль хэдийн бүтсэн гэж үздэг тул агуу гамшиг гартаа атган, юунаас ч айдаггүй бөгөөд тэр өдөр ирэхэд чамайг нэгд нэггүй зохицуулах болно. Хүнийг хүн төгс болгох юм уу, сургамжилж Миний ууган хөвгүүн болгож чадахгүй—энэ асуудал тэр чигтээ Миний урьдчилан тогтоохоос шалтгаалдаг. Миний ууган хөвгүүн гэж хэлсэн хэн боловч ууган хөвгүүн; үүний төлөө тэмцэлдэж, үүнийг булаан авахаар бүү оролд. Бүх зүйл төгс хүчит Бурхан Өөрөө болох Надаас хамаардаг.

Нэг л өдөр Би та бүхэнд Миний захиргааны зарлиг юу болох, Миний уур хилэн гэж юу болохыг харах боломж олгоно (бүгд Миний өмнө сөгдөж, Намайг шүтэн мөргөж, Надаас уучлал эрж, дуулгавартай байх болно; Би одоо Өөрийн ууган хөвгүүдэд л үүний нэг хэсгийг харах боломж олгодог). Би Өөрийн ууган хөвгүүдийг төгс болгохын тулд золиослохоор олон хүнийг сонгосон (Өөрийн ууган хөвгүүдээс бусад хүн бүрийг), агуу улаан лууг зальхай явуулгадаа өөрөө унахад хүргэсэн гэдгээ агуу улаан лууны бүх үр садад харуулах болно. (Миний удирдлагын төлөвлөгөөний үеэр агуу улаан луу Миний удирдлагын төлөвлөгөөнд саад хийх гэж, Миний ууган хөвгүүдээс бусад Надад үйлчлэл үзүүлдэг хүмүүсийг илгээдэг; гэвч тэр зальхай явуулгадаа өөрөө унаж, тэд бүгд Миний ажилд үйлчлэл үзүүлдэг. Энэ нь Би Өөртөө үйлчлэл үзүүлэхээр бүгдийг дайчилна гэдгийн жинхэнэ утга

учрын нэг хэсэг юм.) Өнөөдөр бүх зүйл биелсэн үед Би тэднийг бүгдийг нь үгүй хийж, Өөрийн хөл доор няц дарж, үүгээрээ агуу улаан лууг гутааж, бүрмөсөн шившиг болгоно (тэд худал ярьж, ерөөл хүртэх гэж оролддог ч Надад үйлчлэл үзүүлнэ гэж хэзээ ч бодоогүй)—энэ бол Миний мэргэн ухаан юм. Үүнийг сонсоод хүмүүс Намайг хүйтэн сэтгэлтэй, өршөөлгүй, бас хүн чанаргүй гэж боддог. Би үнэхээр Сатанд бол хүйтэн сэтгэлтэй, өршөөлгүй ханддаг, түүнчлэн Би бол хүн чанараас давсан Бурхан Өөрөө билээ. Чи Намайг хүн чанартай Бурхан гэж яаж хэлж чадна вэ? Чи Намайг энэ ертөнцийнх биш гэдгийг мэддэггүй юм уу? Би бүх зүйлийн дээр байдаг гэдгийг мэддэггүй юм уу? Миний ууган хөвгүүдээс өөр, Над шиг хэн ч үгүй, Миний зан чанартай хэн ч үгүй (хүний зан чанар бус, харин бурханлаг зан чанар), Миний хэв чанарыг эзэмшдэг хэн ч үгүй.

Сүнсний ертөнцийн үүд нээгдэхэд та нар бүх нууцыг харж, ингэснээр чөлөөт ертөнц рүү бүрмөсөн орох, Миний хайрын тэврэлтэд, Миний мөнх ерөөлд орох боломжтой болно. Миний гар хүн төрөлхтнийг үргэлж дэмжиж ирсэн. Гэвч хүн төрөлхтний дунд Миний аврах хэсэг ч бий, аврахгүй хэсэг ч бий. (Миний дэмжлэггүйгээр дэлхий ертөнц бүхэлдээ аль эрт Үхэгсдийн ертөнцөд унах байсан учраас Би “дэмжих” гэж хэлдэг.) Үүнийг ухаар! Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөө. Тэгвэл Миний удирдлагын төлөвлөгөө гэж юу вэ? Би хүн төрөлхтнийг бүтээсэн ч хүн бүрийг олж авна гэж хэзээ ч төлөвлөөгүй, зөвхөн хүн төрөлхтний багахан хэсгийг л олж авна. Тэгвэл Би ийм олон хүнийг яагаад бүтээсэн юм бэ? Миний өмнө нь хэлж байсанчлан, Намайг байхад бүх зүйл эрх чөлөө, чөлөөлөлт бөгөөд Би хүссэн бүхнээ хийдэг. Би хүн төрөлхтнийг бүтээхдээ, тэднийг хэвийн амьдралаар амьдарч, дараа нь хүн төрөлхтний багахан хэсэг нь өндийж Миний ууган хөвгүүд, Миний хөвгүүд, Миний ардууд болоосой гэсэндээ л тэр юм. Миний ууган хөвгүүд, Миний ардууд, Миний хөвгүүдээс бусад бүх хүн, үйл явдал, эд юм бүгд үйлчлэл үзүүлэгчид бөгөөд бүгд мөхөх ёстой гэж хэлж болно. Энэ маягаар, Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө эцэс болно. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөө, энэ бол Миний ажил, Миний үйлддэг алхмууд юм. Бүх зүйл дуусахад Би бүрэн амарна. Тэр үед бүх зүйл сайхан болно; бүх зүйл амар амгалан, аюулгүй болно.

Миний ажлын алхаа маш хурдан болохоор хүний төсөөллөөс давсан байдаг. Энэ нь өдөр бүр өөрчлөгддөг бөгөөд хөл нийлүүлж чадаагүй хэн боловч хохирол амсах болно; хүн өдөр бүр зөвхөн шинэ гэрлээс зуурч чадна (гэхдээ Миний захиргааны зарлиг, Миний нөхөрлөдөг үзэгдэл, үнэн хэзээ ч өөрчлөгддөггүй). Би яагаад өдөр бүр ярьдаг вэ? Би яагаад тогтмол чамайг гэгээрүүлдэг вэ? Үүний доторх жинхэнэ утга учрыг ойлгож байна уу? Ихэнх хүн одоо ч инээж, наргисаар нухацтай байж чадахгүй байна. Тэд зүгээр л Миний үгэнд огт анхаарал хандуулдаггүй, харин сонсох үедээ түрхэн зуур сэтгэлийн түгшүүр л мэдэрдэг. Дараа нь, Миний үг төд удалгүй мартагдаж, тэд удалгүй өөрсдийн ялгамж чанарыг мэдэхээ байж, хайнга болцгоодог. Чи өөрийнхөө байр суурь юу болохыг мэдэх үү? Хүн Надад үйлчлэл үзүүлэх, эсвэл Би урьдчилан тогтоож, сонгох эсэхийг Миний гар л үйлддэг;

үүнийг хэн ч өөрчилж чадахгүй—Би үүнийг Өөрөө хийх ёстой, тэднийг Өөрөө сонгож, урьдчилан тогтоох ёстой. Намайг ухаалаг бус Бурхан гэж хэн хэлж зүрхлэх вэ? Миний хэлдэг үг бүр, хийдэг юм бүхэн Миний мэргэн ухаан юм. Миний удирдлагад дахин нэг удаа саад болж, эсвэл Миний төлөвлөгөөг сүйтгэж хэн зүрхлэх вэ? Тэднийг Би яасан ч уучлахгүй! Цаг хугацаа Миний гарт бий тул хожимдох вий гэж Би айдаггүй; Миний удирдлагын төлөвлөгөө дуусах хугацааг шийддэг Нэгэн нь Би биш гэж үү? Энэ нь бүхэлдээ Миний ганц бодлоос л шалтгаалдаг бус уу? Намайг болсон гэж хэлбэл болж, дууссан гэж хэлбэл дуусдаг. Би огт яараагүй бөгөөд зохих зохицуулалтыг хийх болно. Хүмүүс Миний ажилд хошуугаа дүрэх ёсгүй, тэд Миний төлөө аливааг хүссэнээрээ хийх ёсгүй. Хошуу дүрсэн хэнийг ч болов Би хараадаг—энэ бол Миний захиргааны зарлигийн нэг юм. Би Өөрөө Өөрийнхөө ажлыг хийдэг, өөр хэн ч Надад хэрэггүй (Би үйлчлэл үзүүлэгчдэд үйлдэхийг зөвшөөрдөг, эс бөгөөс тэд яаран, сохроор үйлдэж зүрхлэхгүй). Бүх ажлыг Би зохицуулж, Би шийддэг, учир нь Би цорын ганц Бурхан Өөрөө билээ.

Ертөнцийн бүх улс үндэстэн эрх мэдэл, ашиг хонжооны төлөө бие биетэйгээ тэмцэлдэж, газар нутаг булаацалддаг ч бүү түгш, учир нь энэ бүх зүйл Миний үйлчлэлд байдаг. Тэгэхээр Би яагаад тэдгээрийг Миний үйлчлэлд байдаг гэж хэлдэг вэ? Би хуруугаа ч хөдөлгөлгүй аливааг хийдэг. Сатануудыг шүүхийн тулд Би эхлээд тэднийг хооронд нь маргалдуулж, эцэст нь тэднийг сүйрэлд хүргэн, зальхай явуулгадаа өөрсдөө унахад хүргэдэг (тэд Надтай эрх мэдлийн төлөө тэмцэлдэх хүсэлтэй ч, эцэстээ Надад үйлчлэл үзүүлээд дуусдаг). Би зөвхөн үг хэлж, тушаал өгдөг бөгөөд хүн бүр Миний хий гэснийг хийнэ, эс тэгвээс Би чамайг тэр дор нь устгах болно. Би бүх зүйлийг тушааж, бүх зүйлийг тогтоодог тул эдгээр зүйл бүгд Миний шүүлтийн нэг хэсэг юм. Хэн ч юу ч хийлээ гэсэн өөрийн эрхгүй, Миний зохицуулалтаар тийнхүү хийдэг. Та нар удахгүй болох үйл явдлуудад Миний мэргэн ухаанаар дүүрэн байна гэж Би найдъя. Хуумгай бүү ханд, харин аливаа зүйл чамд тохиолдох үед Надад улам их ойрт; Миний гэсгээлтийг зөрчихөөс зайлсхийж, Сатаны зальхай явуулгад өртөхгүй байхын тулд бүх талаар сэрэмж, болгоомжтой бай. Та нар Миний үгээс мэдлэг ухаан олж авч, Намайг юу болохыг мэдэж, Надад юу байгааг харах хэрэгтэй. Миний учиртай харцны дагуу аливааг хийж, болчимгүй авирлахгүй байх ёстой. Миний хийдгийг хий, Миний хэлдгийг хэл. Алдаа гаргаж, уруу татагдахаас зайлсхийж чадаасай гэсэндээ Би та нарт эдгээрийг урьдчилж хэлдэг. Тэгвэл “Миний оршихуй”, “Миний эзэмшдэг зүйл” гэж юу вэ? Та нар үнэхээр мэдэх үү? Миний эдэлдэг зовлон шаналал бол Миний хэвийн хүн чанарын нэг хэсэг тул Миний оршихуйн нэг хэсэг, мөн Миний оршихуйг Миний бүрэн төгс бурханлаг чанараас олж болно—та нар үүнийг мэдэх үү? Миний оршихуй хоёр талаас бүрддэг: Нэг тал нь Миний хүн чанар бол нөгөөх нь Миний бүрэн төгс бурханлаг чанар юм. Зөвхөн энэ хоёр тал нийлж байж бүрэн төгс Бурхан Өөрөө болдог. Миний бүрэн төгс бурханлаг чанарт мөн нэлээд олон зүйл багтдаг: Би ямар ч хүн, хэрэг явдал, юмсын хязгаарлалтад ордоггүй; Би бүх орчноос давсан; Би цаг хугацаа,

орон зай, газар зүйн ямар ч хязгаарлалтад баригддаггүй; Би бүх хүн, хэрэг явдал, юмсыг Өөрийн гарын таван хуруу шигээ үнэхээр мэддэг; гэсэн атлаа Би мах цуснаас бүрдсэн бөгөөд биет хэлбэрээр оршдог; хүмүүсийн нүдэнд Би энэ үнэн бие хэвээр боловч уг чанар нь өөрчлөгдсөн—махбод бус, харин бие юм. Эдгээр нь үүний ердөө багахан хэсэг нь. Миний бүх ууган хөвгүүн ирээдүйд мөн ийм байх болно; энэ бол алхах ёстой зам бөгөөд үйл нь ирсэн хүмүүс зугтаж чадахгүй. Намайг үүнийг хийж байх хооронд урьдчилан тогтоогдоогүй бүх хүн хөөгдөнө (учир нь, Сатан үүгээр Миний үг үнэн зөв эсэхийг харах гэж Намайг сорьж байгаа юм). Урьдчилан тогтоогдсон хүмүүс хаа ч явсан үүнээс зайлж чадахгүй, үүгээр та нар Миний үйл хэргийн цаад зарчмыг харах болно. “Миний эзэмшдэг зүйл” гэдэг нь Миний мэргэн ухаан, Миний мэдлэг, Миний овсгоо самбаа, бас Миний хэлдэг үг бүрийг хэлж байна. Миний хүн чанар, Миний бурханлаг чанарын аль алинд нь энэ байдаг. Өөрөөр хэлбэл, Миний хүн чанарын хийдэг бүхэн, Миний бурханлаг чанарын хийдэг бүхэн Миний эзэмшдэг зүйл; үүнийг хэн ч булааж эсвэл салгаж авч чадахгүй; тэдгээр нь Миний өмчлөлд байдаг бөгөөд үүнийг хэн ч өөрчилж чадахгүй. Энэ бол Миний хамгийн хатуу захиргааны зарлиг (учир нь, хүний үзлээр бол Миний хийдэг олон зүйл тэдний үзэлтэй нийцдэггүй бөгөөд хүний ойлголтоос давсан байдаг; энэ бол хүн нэг бүрийн хамгийн амархан зөрчдөг зарлиг бөгөөд хамгийн хатуу нь тул тэдний амьдрал тийнхүү хохирол амсдаг). Би дахин хэлье, Миний хий гэж захиж байгаа зүйлд та нар ухамсартай хандах ёстой—хайнга хандаж болохгүй!

96-Р БҮЛЭГ

Надаас төрсөн атлаа Намайг мэддэггүй бүх хүнд Өөрийн уур хилэн, агуу хүч, бүх мэргэн ухааныг харуулахын тулд Би тэднийг гэсгээнэ. Миний дотор бүх зүйл зөвт бөгөөд зөвт бус, шударга бус байдал, заль мэх огт байхгүй; шударга бус, зальхай хэн боловч Үхэгсдийн оронд төрсөн тамын хүү байж таарна. Миний дотор бүх зүйл ил тод; Миний гүйцэлдэнэ гэж хэлсэн бүхэн гүйцэлдэж, бий болно гэж хэлсэн бүхэн бий болдог бөгөөд Би цорын ганц Бурхан Өөрөө тул эдгээр зүйлийг хэн ч өөрчилж, дуурайж чадахгүй. Болох гэж буй зүйлд Миний урьдчилан тогтоож, сонгосон ууган хөвгүүдийн бүлэгт багтсан хүн бүр нэг нэгээрээ илчлэгдэх ба ууган хөвгүүдийн бүлэгт ороогүй хүн бүрийг Би үүгээр дамжуулж таягдан хаяна. Би Өөрийн ажлыг ингэж хийж, гүйцэлдүүлдэг. Яг одоо Би ууган хөвгүүддээ Өөрийн гайхамшигт үйл хэргийг харуулахын тулд л зарим хүнийг ил болгож байгаа ч дараа нь Би ийм маягаар ажиллахгүй. Харин үнэн дүр төрхөө нэг нэгээр нь ил харуулахыг тэдэнд зөвшөөрөхийн оронд Би ерөнхий нөхцөл байдлаас эхлэнэ (чөтгөрүүд бүгд ерөнхийдөө адилхан учир ердөө цөөхнийг нь л жишээ болгон авахад хангалттай). Миний бүх ууган хөвгүүний зүрх сэтгэл нь тодорхой бөгөөд үүнийг Би цааш ярих шаардлагагүй (учир нь тогтсон цагт тэд нэг нэгээрээ илчлэгдэх нь лавтай).

Хэлсэн үгэндээ эзэн болдог нь Миний зан чанар бөгөөд Надад нууж, далдалсан зүйл байдаггүй. Би та нарын ойлгох хэрэгтэй юм бүхнийг нэг бүрчлэн хэлнэ, харин та нарыг бат зогсож чадахгүй байх вий гэсэндээ та нарын мэдэх учиргүй зүйлийг яасан ч хэлэхгүй. Ялихгүй юмтай зууралдаад, чухал зүйлсийг бүү алд—ингэх нь үнэхээр ашиггүй. Төгс хүчит Бурхан гэдэгт минь итгэ, тэгвэл бүх зүйл гүйцэлдэж, бүгд амархан, таатай болно. Би аливааг ингэж хийдэг. Итгэдэг хэнд ч бай Би харах боломж олгодог ба итгэдэггүй хэнд ч бай, Би мэдэх боломж олгодоггүй, хэзээ ч түүнд ойлгуулахгүй. Надад сэтгэл хөдлөл, өршөөл гэж үгүй, Миний гэсгээлтэд халддаг хэнийг ч болов Би түдгэлзэлгүй лавтай хөнөөж, бүгдэд нь адилхан хандана. Би хүн бүрд ижил байдаг—Надад хувийн санал бодол гэж үгүй бөгөөд яавч сэтгэлийн хөдлөлөөр үйлддэггүй. Үүнээс хүмүүс Миний зөвт байдал, сүр жавхланг харахгүй байж яаж чадах юм бэ? Энэ бол хэний ч өөрчилж чадахгүй, бас хэний ч бүрэн мэдэж чадахгүй Миний мэргэн ухаан, Миний зан чанар юм. Миний гар үргэлж, цаг үргэлж бүхнийг тушаадаг бөгөөд Би бүхнийг Миний төлөө хэдийд ч дуулгавартай үйлчлэл хийхэд бэлэн байлгах гэж үргэлж зохицуулдаг. Миний удирдлагын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд олон хүн үйлчлэл хийж байгаа, харин эцэстээ тэд ерөөл харах боловч эдэлж чаддаггүй нь яасан өрөвдөлтэй вэ! Гэвч Миний зүрх сэтгэлийг хэн ч өөрчилж чадахгүй. Энэ бол Миний захиргааны зарлиг (захиргааны зарлигийн тухай дурдах бүр энэ нь хэний ч өөрчилж үл чадах зүйл гэдгийг хэлдэг учир Би хожим ярих үедээ ямар нэг зүйл хийхээр шийдсэн бол тэр нь лавтайяа Миний захиргааны зарлиг мөн. Санаж яв! Хохирол амсахгүйн тулд үүнийг бүү зөрч), мөн энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Энэ бол дурын хүний хийж чадах зүйл бус, Миний Өөрийн ажил билээ. Би үүнийг хийх ёстой—Би үүнийг зохицуулах ёстой, Миний бүхнийг чадагч чанарыг харуулж, Миний уур хилэнг үзүүлэхэд энэ нь хангалттай.

Ихэнх хүн Миний хүн чанарын талаар одоо ч мэддэггүй, ойлгодоггүй. Би хэдэн удаа хэлсэн ч, та нар будилсан хэвээр байж, нэг их ойлгодоггүй. Гэвч энэ бол Миний ажил, тэгээд одоо, энэ цаг үед мэддэг нь мэдэж, мэддэггүй нь мэдэхгүй л бай, Би хэнийг ч хүчлэхгүй. Энэ ийм л байж болно. Би энэ талаар тодорхой хэлсэн тул дараа нь үүнийг дахиж ярихгүй (учир нь Би хэтэрхий ихийг хэлсэн, маш тодорхой ярьсан. Намайг мэддэг хүн үнэхээр Ариун Сүнсний ажилтай ба Миний ууган хөвгүүдийн нэг гэдэг нь эргэлзээгүй. Намайг мэддэггүй хүн ууган хөвгүүн яавч биш бөгөөд Би тэр хүнээс Өөрийн Сүнсийг аль хэдийн буцаан авсныг нотолдог). Гэвч эцэстээ Би хүн бүрд Өөрийгөө мэдүүлнэ—Өөрийн хэвийн хүн чанар, Өөрийн бурханлаг чанарын аль алинаар Өөрийгөө бүрэн мэдүүлнэ. Эдгээр нь Миний ажлын алхам бөгөөд Би ийм маягаар ажиллах ёстой. Энэ нь мөн Миний захиргааны зарлиг юм. Хүн бүр Намайг цорын ганц жинхэнэ Бурхан гэж дуудаж, зогсолтгүй уухайлан магтах ёстой.

Миний удирдлагын төлөвлөгөө аль хэдийн бүрэн биелж, бүх зүйл аль эртнээс гүйцэлдчихээд байна. Хүний нүдэнд бол Миний олон ажил одоо ч ид дундаа яваа

мэт харагдавч Би үүнийг аль хэдийн зохих ёсоор зохицуулчихсан бөгөөд Миний алхмын дагуу нэг нэгээрээ биелэх л үлдээд байна (үүний учир нь, дэлхий ертөнцийг бүтээхээс өмнө Би хэн нь шалгалтад бат зогсож чадах, хэн нь Надаар сонгогдож, урьдчилан тогтоогдож чадахгүй, мөн хэн нь Миний зовлонг хуваалцаж чадахгүйг урьдчилан тогтоосон юм. Миний зовлонг хуваалцаж чадах хүмүүс, өөрөөр хэлбэл, Миний урьдчилан тогтоож, сонгосон хүмүүсийг Би лавтай үлдээж, бүхнийг даван гарах боломж олгоно). Чиг үүрэг бүрд хэн байхыг Би зүрх сэтгэлдээ тодорхой мэддэг. Хэн нь Надад үйлчлэл хийдгийг, хэн нь ууган хөвгүүн, хэн нь Миний хөвгүүд, ардуудын нэг гэдгийг Би сайн мэддэг. Би үүнийг арван хуруу шигээ мэддэг. Урьд нь Би ууган хөвгүүн гэж хэлсэн хэн боловч одоо бас л ууган хөвгүүн хэвээрээ, харин ууган хөвгүүн биш гэж урьд хэлсэн нь одоо бас л ууган хөвгүүн биш. Би юу ч хийсэн харамсдаггүй, хийснээ амархан өөрчилдөггүй. Би хэлсэндээ хүрдэг (Надад хөнгөн хуумгай зүйл байдаггүй), тэгээд энэ нь хэзээ ч өөрчлөгддөггүй! Надад үйлчлэл хийдэг хүмүүс үргэлж үйлчлэл хийдэг: Тэд бол Миний үхэр сүрэг; тэд бол Миний адуу (гэхдээ энэ хүмүүс сүнсээрээ хэзээ ч гэгээрдэггүй; Би тэднийг ашиглаж байхад тэд хэрэгтэй, харин ашиглахгүй байх үедээ Би тэднийг хөнөөдөг. Би үхэр, адууны талаар ярихдаа сүнсэндээ гэгээрээгүй, Намайг мэддэггүй, Надад дуулгаваргүй байдаг хүмүүсийг хэлж байна. Тэд хэчнээн дуулгавартай, номхон, гэнэн, үнэнч байлаа ч гэсэн жинхэнэ үхэр, адуу мөн хэвээрээ байдаг). Одоо ихэнх хүмүүс Миний өмнө садар самуун, эрээ цээргүй байж, замбараагүй ярьж, инээж хөхрөн, тоомсоргүй аашилдаг—тэд Миний бурханлаг чанарыг бус, хүн чанарыг л хардаг. Миний хүн чанар эдгээр ааш авирыг өнгөрөөж, Би тэднийг өршөөж чаддаг ч Миний бурханлаг чанарт энэ тийм ч амаргүй. Би ирээдүйд Намайг доромжлон нүгэл үйлдсэн гэдгийг чинь шийдэх болно. Өөрөөр хэлбэл, Миний хүн чанарт халдаж болох ч Миний бурханлаг чанарт болохгүй бөгөөд Надтай өчүүхэн төдий ч сөргөлдсөн хэнийг ч Би тэр даруй огт хойшлуулалгүй шүүнэ. Чи энэ хүнтэй буюу Надтай олон жил холбоотой байж, Намайг сайн мэддэг болсон гээд хайнга ярьж, авирлаж болно гэж бүү бод. Би үнэндээ тоохгүй! Тэр хүн хэн байх нь хамаагүй, Би зөвт байдлаар хандана. Энэ бол Миний зөвт байдал.

Илчлэлийн үе шатуудыг даган Миний нууц өдөр өдрөөр хүмүүст илчлэгдэж, өдрөөс өдөрт тодорхой болж байгаа нь Миний ажлын алхааг харуулахад хангалттай юм. Энэ бол Миний мэргэн ухаан (Би үүнийг шууд хэлдэггүй. Би Өөрийн ууган хөвгүүдийг гэгээрүүлж, агуу улаан лууны үр садыг сохолдог). Түүнчлэн, өнөөдөр Би та нарт Өөрийн Хүүгээр дамжуулан Өөрийн нууцыг илчлэх болно. Та нарыг нэгд нэгэнгүй мэдэг, тодорхой ойлголттой болог гээд хүмүүсийн ой тойнд багтамгүй зүйлийг өнөөдөр Би та нарт илчилнэ. Үүнээс гадна энэ нууц Миний ууган хөвгүүдээс бусад хүн бүрийн дотор байдаг ч, хэн ч үүнийг ойлгож чаддаггүй. Хэдийгээр энэ нь хүн бүрийн дотор байдаг ч хэн ч үүнийг таньж чаддаггүй. Би юу гэж хэлж байна вэ? Энэ үе дэх Өөрийн ажил, Өөрийн айлдварт Би үргэлж агуу улаан луу, Сатан, диавол, тэргүүн тэнгэрэлчийн тухай дурддаг. Тэдгээр нь юу вэ?

Тэд ямар холбоотой вэ? Эдгээр зүйлд юу илэрдэг вэ? Агуу улаан лууны илрэл нь Намайг эсэргүүцдэг, Миний үгийн утгыг ойлгож, ухаарах нь дутмаг, Намайг дандаа хяхан хавчдаг ба Миний удирдлагад саад хийхийн тулд явуулга ашиглах гэдэг. Сатан дараах байдлаар илэрдэг: Надтай эрх мэдлийн төлөө тэмцэлддэг, Миний сонгосон ардуудыг эзэмшихийг хүсдэг, Миний ардуудыг мэхлэх гэж сөрөг үг гаргадаг. Диаволын илрэл нь (Миний нэрийг хүлээн зөвшөөрдөггүй, итгэдэггүй хүмүүс бүгд диавол) дараах байдалтай: махан биеийн таашаалд шунадаг, муу хуял тачаалд автдаг, Сатаны хүлээсэнд амьдардаг, Намайг зарим нь эсэргүүцэж, зарим нь дэмждэг (гэхдээ тэд бол Миний хайртай хөвгүүд гэдгийг нотолдоггүй). Тэргүүн тэнгэрэлчийн илрэл дараах шинжтэй: давлиун ярьдаг, сүсэг бишрэлгүй, хүмүүст зааж сургах гээд үргэлж Миний дууны өнгийг дуурайдаг, гаднаа Намайг дуурайхад л анхаарч, иддэгийг минь идэж, ашигладгийг минь ашигладаг; товчхондоо Надтай эн зэрэгцэхийг хүсдэг, алдар нэрд дуртай боловч Миний хэв чанар дутдаг, Миний амь үгүй, хэрэггүй нэг хог байдаг. Сатан, диавол, тэргүүн тэнгэрэлч гурав нь бүгд агуу улаан лууны нийтлэг баримт тул Надаар урьдчилан тогтоогдож, сонгогдоогүй хүмүүс бүгд агуу улаан лууны үр сад мөн: Энэ бол гарцаагүй! Тэд бүгд Миний дайснууд. (Гэвч Сатаны үймүүлэхийг оролцуулаагүй. Хэрвээ уг чанар чинь Миний хэв чанар бол хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Та нар одоо бас л махбодод амьдарч байгаа тул Сатаны сорилттой үе үе тулгарна—энэ бол зайлшгүй—гэхдээ та нар үргэлж болгоомжтой байх ёстой). Тиймээс Би Өөрийн ууган хөвгүүдээс бусад агуу улаан лууны бүх үр садыг хаях болно. Тэдний уг чанар хэзээ ч өөрчлөгдөж чадахгүй, энэ нь Сатаны хэв чанар юм. Тэд диаволыг илтгэдэг, тэд тэргүүн тэнгэрэлчийг амьдран харуулдаг. Энэ бүхэлдээ үнэн. Миний ярьж байгаа агуу улаан луу бол нэг том улаан луу биш; харин Намайг эсэргүүцдэг муу ёрын сүнс бөгөөд “агуу улаан луу” гэдэг нь адилхан утгатай үг юм. Тэгэхээр Ариун Сүнснээс бусад бүх сүнс бол муу ёрын сүнс бөгөөд агуу улаан лууны үр сад гэж хэлэхэд болно. Үүнийг хүн бүр тов тодорхой ойлгох хэрэгтэй.

97-Р БҮЛЭГ

Би хүн бүрд Өөрийн гайхамшигт үйл хэргийг үзүүлж, Өөрийн ухаалаг үгийг сонсгоно. Үүнд нь хүн нэг бүр багтах ёстой, мөн зүйл нэг бүрээр дамжин тохиолдох ёстой. Энэ бол Миний захиргааны зарлиг, Миний уур хилэн. Би хүн нэг бүр, зүйл нэг бүрийг хөндөж, ингэснээр орчлон ертөнцийн нэг захаас нөгөөг хүртэл хаа сайгүй бүх хүн өөрсдийн нүдээр харах болно; үүнийг биелэхээс нааш Би хэзээ ч үл зогсоно. Миний уур хилэн өчүүхэн төдий ч түдгэлзэлгүй бүрэн оргилсон. Энэ нэрийг хүлээн зөвшөөрсөн хүн бүрд Миний уур хилэн чиглэдэг (удахгүй дэлхий ертөнцийн бүх улс үндэстнийг чиглэх болно). Тэгэхээр Миний уур хилэн гэж юу вэ? Хэр зэрэг ширүүн бэ? Ямар хүн дээр Миний уур хилэн буудаг вэ? Уур хилэн бол уурын

хамгийн догшин ширүүн түвшин гэж олон хүн боддог ч энэ нь үүнийг бүрэн тайлбарлахгүй байна. Миний уур хилэн болон Миний захиргааны зарлиг бол хоёр салшгүй хэсэг юм; Би Өөрийн захиргааны зарлигийг хэрэгжүүлэхэд, үүнийг уур хилэн дагадаг. Тэгвэл уур хилэн гэж яг юу вэ? Уур хилэн нь хүмүүст Миний оноодог шүүлтийн нэг түвшин бөгөөд Миний захиргааны аль ч зарлигийн хэрэгжүүлэлтийн цаана байдаг зарчим юм. Миний зарлигийн нэгийг зөрчсөн хэнд ч болов аль зарлигийг зөрчсөнөөс хамааран, Миний уур хилэн зохих түвшинд буух болно. Миний уур хилэн байх үед Миний захиргааны зарлиг бас байх нь гарцаагүй бөгөөд мөн эсрэгээрээ байдаг. Миний захиргааны зарлиг, уур хилэн хоёр салшгүй нэг бүхэл болдог. Энэ бол хэн ч зөрчиж болохгүй хамгийн хатуу шүүлт билээ. Бүх хүн үүнийг дагах ёстой, эс бөгөөс Миний гарт цохиулж унахаас зайлсхийхэд хэцүү байх болно. Хүмүүс эрин үеүдийн туршид энэ тухай хэзээ ч мэдээгүй (хэдийгээр зарим хүн агуу гамшгаас үүдсэн өвчин шаналлыг туулсан ч, энэ тухай мэдэхгүй л байсан; гэхдээ энэхүү захиргааны зарлиг нь үндсэндээ одоогоос хэрэгжиж эхэлж байна), харин өнөөдөр Би та нарыг зөрчил үүсгэхээс зайлсхийг гэж үүнийг бүгдэд нь илчилж байна.

Бүх хүн Миний дуу хоолойг сонсож, Миний үгэнд итгэх ёстой. Эс бөгөөс Би юу ч үйлдэхгүй, ямар ч ажил хийхгүй. Миний үг, үйлдэл бүр та нарын дагах ёстой жишээ; тэдгээр нь та нарын дагах үлгэр дуурайл, жишиг юм. Би махбод болсны шалтгаан нь та нарт Өөрийн хүн чанар дахь Би юу болох, Надад юу байдгийг харуулах гэснийх. Ирээдүйд Би та нарт Өөрийн бурханлаг чанар дахь Би юу болох, Надад юу байдгийг үзүүлэх болно. Аливаа зүйл энэ маягаар алхам алхмаар үргэлжлэх ёстой. Эс бөгөөс, хүмүүс зүгээр л итгэж чадахгүй, Миний талаар ямар ч мэдлэггүй байх болно. Харин тэдэнд тодорхойгүй, бүрхэг үзэгдэл л байх бөгөөд Миний тухай тодорхой ойлголтой байж чадахгүй. Миний үнэн бие та нарт бүрэн илэрсэн гэдгийг Миний үг харуулсан атал хүмүүс мунхаг, мэдлэггүй гэх цорын ганц шалтгааны улмаас Миний үгийг сонссон ч Намайг мэдэхгүй хэвээр байна. Одоо ч гэсэн Намайг бие махбодтой болсон байхад хүмүүс үл тоосоор байгаа учир Би энэхүү хорон муу, садар самуун хуучин эрин үеийг шийтгэж, Сатан болон диаволуудыг бүрмөсөн шившиглэхийн тулд Өөрийн уур хилэн, захиргааны зарлигийг хэрэглэнэ. Энэ бол цорын ганц зам; хүн төрөлхтний хүрэх газар, хүн төрөлхтнийг хүлээж байгаа төгсгөл юм. Үр дүн нь аль хэдийн шийдэгдсэн бөгөөд хэн ч өөрчилж, эсвэл шалтаг хэлэн зайлсхийж чадахгүй. Би л эцсийн шийдвэрийг гаргана; энэ бол Миний удирдлага, Миний төлөвлөгөө. Хүмүүс бүгд зүрх сэтгэлдээ, үг хэлээрээ итгэж, үнэмшсэн байх ёстой. Энэ амьдралд сайн хувь заяа олж авсан хүмүүс үүрд мөнх зовох нь лавтай бол энэ амьдралд зовсон хүмүүс үүрд мөнх ерөөгдөх нь лавтай—үүнийг Би урьдчилан тогтоосон бөгөөд хэн ч өөрчилж чадахгүй. Хэн ч Миний зүрх сэтгэлийг өөрчилж чадахгүй, хэн ч Миний үгэнд ганц ч илүү үг нэмж болохгүй, нэг ч үгийг дур мэдэн авч хаяхыг тэдэнд бүр ч зөвшөөрөхгүй; хэрэв хэн нэгэн үүнийг зөрчвөл Би түүнийг лавтай гэсгээнэ.

Өдөр бүр Миний нууц та нарт илчлэгддэг—та нар үнэхээр тэдгээрийг ойлгодог уу? Үнэхээр энэ талаар тодорхой мэддэг үү? Сатан чамайг мэхэлж байхад чи үүнийг нэвт харж чадах уу? Та нарын амин дахь биеийн хэмжээгээр үүнийг тогтоодог. Бүх зүйлийг Би урьдчилан тогтоодог гэж Би хэлдэг юм бол Өөрийн ууган хөвгүүдийг төгс болгохын тулд яагаад биечлэн бие махбодтой болсон юм бэ? Түүнчлэн, Би яагаад хүмүүсийн хэрэггүй гэж боддог ийм их ажил хийсэн юм бэ? Будилаад байгаа нь Би юм уу? Үүнийг санаж яв! Миний хийдэг юм бүхэн зөвхөн ууган хөвгүүдээ олж авахын тулд бус, бүр чухал нь Сатаныг шившиглэхийн тулд байдаг. Хэдийгээр, Сатан Намайг эсэргүүцдэг ч, Би түүний үр удмыг өөрийнх нь эсрэг босгож, Намайг магтахад хүргэх хүч чадалтай. Түүнчлэн, дараагийн ажлын алхам саадгүй явж, бүхий л ертөнц Намайг уухайлан магтаж, амьсгалдаг бүхэн Надад өвдөг сөгдөж, Намайг алдаршуулаасай гэж Би бүхнийг хийдэг; энэ үнэхээр суу алдрын өдөр байх болно. Би бүх зүйлийг Өөрийн гарт атгадаг бөгөөд долоон аянга нүргэлэхэд бүх зүйл бүрмөсөн бүтэж, хэзээ ч өөрчлөгдөлгүй, бүгд тогтворжих болно. Тэр үеэс хойш шинэ тэнгэр, газрын шинэ амьдралд орж, бүхэлдээ шинэ орчинд орж, хаанчлалын амьдрал эхлэх болно. Гэхдээ хаанчлал дотор байхад ямар вэ? Хүмүүс үүнийг зүгээр л сайн ойлгож чадахгүй (хаанчлалын амьдралын амтыг урьд өмнө нь үзсэн хэн ч үгүй учир, хүмүүс оюун ухаандаа л төсөөлж, зүрх сэтгэлдээ л эргэцүүлж ирсэн). Чуулганы амьдралаас хаанчлалын амьдралд шилжих нь одоогийн байдлаас ирээдүйн байдалд шилжиж байгаа явдал бөгөөд энэ үед хүмүүсийн урьд нь хэзээ ч төсөөлөөгүй олон зүйл тохиох болно. Чуулганы амьдрал бол хаанчлалын амьдралд орох урьдач нөхцөл учир хаанчлалын амьдрал бий болохоос өмнө Би чуулганы амьдралыг дэмжиж тэтгэхэд бүхий л хүчин чармайлтаа зарцуулна. Чуулганы амьдрал гэж юу вэ? Энэ нь, Миний ууган хөвгүүдийг оролцуулаад хүн бүр Миний захиргааны зарлиг, Миний шүүлт, Миний уур хилэнг ойлгож, хаанчлалын амьдралд зөрчилд гаргахаас зайлсхийхийн тулд Миний үгийг идэж, ууж, таашааж, Намайг мэдэж, тэгснээрээ Миний шатаалт, ариусгалтыг хүлээн авч байгаа явдал юм. Тэгвэл хаанчлалын амьдрал гэж юу вэ? Хаанчлалын амьдрал гэдэг бол Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчилж, бүх ард түмэн, бүх улс үндэстнийг захирах явдал юм (зөвхөн Би болон Миний ууган хөвгүүд л хаанчлалын амьдралыг эдэлж чадна). Хэдийгээр бүх ард түмэн, бүх улс үндэстнээс ирсэн Миний хөвгүүд, Миний ардууд хаанчлалд орох ч, тэд хаанчлалын амьдралыг эдэлж чадахгүй. Хаанчлалын амьдралыг зөвхөн сүнсний ертөнцөд орсон хүмүүс л эдэлж чадна. Иймээс зөвхөн Би болон Миний ууган хөвгүүд л биед амьдарч чаддаг байхад Миний хөвгүүд, Миний ардууд махан биед амьдарсан хэвээр байна. (Гэвч Сатаны завхруулсан нь махан бие биш. Энэ нь Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчлахын ач холбогдол юм.) Бусад бүх хүний сүнс, сэтгэл, биеийг авч, Үхэгсдийн орон руу чулуудна. Өөрөөр хэлбэл, энэ хүмүүс бүрмөсөн мөхөж, оршихоо болно (гэсэн атлаа тэд зовлон бэрхшээл, гай гамшиг зэрэг Сатаны бүх хүлээс, харгислалыг туулах ёстой). Энэ нь дуусмагц хаанчлалын амьдрал

албан ёсоор голдиролдоо орж, Би Өөрийн үйл хэргийг албан ёсоор илчилж эхэлнэ (нуулгүй, нээлттэй илчилнэ). Тэр цагаас эхлэн санаа алдалт, нулимс дахиж яавч байхгүй. (Учир нь, хүмүүст хор хөнөөл учруулж, тэднийг уйлж, зовж шаналахад хүргэдэг юу ч байхгүй болох бөгөөд энэ нь Миний хөвгүүд, Миний ардуудад ч бас хамаатай; гэхдээ Миний хөвгүүд, Миний ардууд үүрд махан биед байна гэдэг нь энд онцлох ёстой нэг зүйл юм.) Бүгд баясалтай, баяр хөөртэй харагдана. Энэ нь биет зүйл биш, бодит нүдээр харж болохгүй зүйл байх болно. Миний ууган хөвгүүд болох хүмүүс ч бас үүнийг эдэлж чадна; энэ бол Миний гайхамшигт үйл хэрэг, Миний агуу хүч чадал юм.

Би та нарыг цаг үргэлжид Миний хүслийг эрж хайж, Миний зүрх сэтгэлд санаа тавьж чаддаг байгаасай гэж хүсэж байна. Зуурдын жаргал бүхий л амьдралыг чинь сүйрүүлж чадах бол, зуурдын зовлон мөнхийн ерөөлийг авчирч чадна. Битгий дүнсгэр бай; энэ бол алхах ёстой зам. Би өмнө нь үргэлж хэлдэг байсан: “Миний төлөө чин сэтгэлээсээ зарлагаддаг хүмүүсийг Би асар ихээр ерөөх нь гарцаагүй.” Тэгэхээр “ерөөл” гэж юу вэ? Тэдгээр нь зөвхөн өнөөдөр олж авдаг зүйл бус, харин ч ирээдүйд эдлэх учиртай зүйл юм—зөвхөн энэ л жинхэнэ ерөөл мөн. Энэ нь Миний ерөөл учир, та нар Сион ууланд эргэн ирэх үедээ одоогийн зовлондоо эцэс төгсгөлгүй талархаж байгаагаа харуулах болно. Одоо махан биед амьдарна гэдэг Сион уулан дээр байгаа (чи Миний дотор амьдардаг гэсэн үг) хэрэг бол, маргааш биед амьдрах нь суу алдрын өдөр байх бөгөөд энэ нь Сион уулан дээр байгаа хэрэг бүр ч мөн. Миний хэлсэн энэ үгийг сонсоод та нар “Сион уул” гэдэг нь юу гэсэн утгатай болохыг ойлгодог. Сион уул гэдэг бол хаанчлал гэдэгтэй ижил үг бөгөөд бас сүнсний ертөнц юм. Өнөөдрийн Сион уулан дээр та нар махан биед тайтгарал хүлээн авч, Миний нигүүлслийг олж авч байна; ирээдүйн Сион ууланд та нар биед орж, хаанчлах ерөөлийг эдлэх болно. Үүнийг огт үл тоомсорлох ёсгүй. Тэгээд ерөөл олж авч болох цаг үеийг огт өнгөрөөж болохгүй; өнөөдөр бол эцсийн эцэст өнөөдөр бөгөөд маргаашаас тун өөр. Чи ерөөл эдэлж эхлэх үедээ өнөөдрийн нигүүлслийг дурдаад ч хэрэггүй гэж бодох болно. Энэ бол Миний чамд даалгадаг зүйл, бас Миний эцсийн зөвлөгөө.

98-Р БҮЛЭГ

Бүх зүйл та нарын нэг бүр дээр чинь ирж, Миний тухай илүү их мэдэж, Надад илүү бат итгэлтэй байх боломж олгоно. Тэдгээр нь нэгэн Бурхан Өөрөө болох Намайг, Төгс Хүчит Намайг, бие махбодтой болсон Бурхан Өөрөө болох Намайг мэдэх боломжийг чамд олгоно. Үүний дараа Би махбодоос гарч, Сион руу, Миний амьдран суудаг газар, Миний хүрэх газар, бүх зүйлийг бүтээсэн бааз суурь минь болох Канааны сайхан нутаг руу буцах болно. Одоо та нарын хэн чинь ч Миний хэлж байгаа үгийг ойлгохгүй байгаа; эдгээр үгийн утгыг ойлгож чадах ганц ч хүн

байхгүй. Зөвхөн бүх зүйлийг та нарт илчилсний дараа л та нар Намайг яагаад ийм үг хэлж байгааг ойлгоно. Би энэ дэлхийнх биш, энэ орчлон ертөнцийнх бүр ч биш, учир нь Би нэгэн Бурхан Өөрөө билээ. Би бүхий л орчлонг Өөрийн гарт атгаж, Би Өөрөө үүнийг хариуцаж, хүмүүс зөвхөн Миний эрх мэдэлд захирагдаж, Миний ариун нэрийг хэлж, Миний төлөө уухайлж, Намайг магтаж л чадна. Бүх зүйл аажмаар та нарт илчлэгдэнэ. Хэдийгээр, юу ч далд биш боловч та нар Миний ярьж байгаа байдал, Миний үгийн өнгийг ойлгож чадахгүй л байна. Та нар Миний удирдлагын төлөвлөгөө ямар учиртайг ойлгохгүй л байна. Тиймээс, Би та нарт Өөрийн минь хэлснээс ойлгогдоогүй бүх зүйлийг хэлж өгнө, учир нь Надад бүх зүйл энгийн, тодорхой байхад та нарт асар хэцүү санагдаж, ерөөс огт ойлгодоггүй. Тийм болохоор, Би Өөрийн ярьдаг аргыг өөрчилж, ярихдаа аливааг хооронд нь холбохоо больж, зөвхөн асуудал бүрийг нэг нэгээр нь тодруулах болно.

Үхлээс амилах гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь махан биед үхээд, үхсэнийхээ дараа биед эргэж ирнэ гэсэн үг үү? Үүнийг үхлээс амилах гэж хэлдэг үү? Энэ тийм энгийн гэж үү? Би бол төгс хүчит Бурхан; чи энэ талаар юу мэдэх вэ? Үүнийг хэрхэн ойлгож байна вэ? Намайг анх бие махбодтой болох үеийн үхлээс амилсныг минь үнэхээр шууд утгаар нь ойлгож болох уу? Үйл явц нь үнэхээр тэдгээр бичвэрт дүрсэлсэн шиг байсан уу? Би хэрвээ илэн далангүй ярихгүй бол, хүмүүст тодорхой хэлэхгүй бол, Миний үгийн утга учрыг хэн ч ойлгож чадахгүй гэдгийг хэлсэн. Эрин үеүдийн туршид үхлээс амилах гэдэг тийм зүйл байсан гэж бодоогүй ганц ч хүн үгүй. Дэлхий ертөнц бүтээгдсэн цагаас хойш үүний жинхэнэ утга учрыг хэн ч ойлгож байгаагүй. Би үнэхээр загалмайд цовдлогдсон уу? Тэгээд үхсэний дараа Би булшнаас гарч ирсэн уу? Үнэхээр тийм зүйл болсон гэж үү? Энэ үнэхээр үнэн байж болох уу? Эрин үеүдийн туршид үүнд хэн ч, ямар ч хичээл зүтгэл гаргаагүй, үүнээс хэн ч Намайг мэддэг болоогүй, үүнд итгэдэггүй ганц ч хүн байдаггүй; бүгд л үүнийг үнэн гэж боддог. Миний үг бүхэн далд утгатайг тэд мэддэггүй. Тэгвэл үхлээс амилах гэж яг юу вэ? (Ойрын ирээдүйд, та нар үүнийг туулах учраас Би та нарт энэ тухай урьдчилан хэлье.) Бүх бүтээгдсэн зүйл үхэхийг хүсдэггүй; тэд бүгд амьдрахыг хүсдэг. Миний өнцгөөс бол, махбодын үхэл гэдэг жинхэнэ үхэл биш. Миний Сүнс хүнээс буцахад тэр хүн үхдэг. Иймээс Би Сатаны завхруулсан тэр бүх чөтгөрийг (итгэл байхгүй хүмүүс бүгд шүтлэггүй хүмүүс) үхсэн гэж хэлдэг. Дэлхий ертөнц бүтээгдсэн цагаас хойш Би Өөрийн сонгосон хүн бүрд Өөрийн Сүнсийг өгсөн. Гэвч бүтээлийн цагийн дараах үе шатаас хойш хүмүүс хэсэг хугацаанд Сатанд эзлэгдсэн. Тиймээс, Би явж, хүмүүс зовж эхэлсэн (ярьсанчлан, махбод болж загалмайд цовдлуулах үедээ Миний туулсан зовлон). Гэвч, Би Өөрийн урьдчилан тогтоосон цагт (Би хүмүүсийг орхиж явах үе дуусах үед) Өөрийн урьдчилан тогтоосон хүмүүсийг эргүүлэн олж авч, та нарт дахин нэг удаа Өөрийн Сүнсийг байрлуулснаар та нар дахин амь орсон. Үүнийг “үхлээс амилах” гэдэг. Одоо үнэхээр Миний Сүнсэнд амьдардаг хүмүүс бүгд аль хэдийн ер бусын болж, бүгд биед амьдардаг. Гэвч удахгүй та нар сэтгэлгээ, үзлээ, хорвоогийн бүх ээдрээг

хөсөр хаях болно. Гэвч, энэ нь хүмүүсийн төсөөлдөг шиг зовсны дараа үхлээс амилж байгаа хэрэг биш юм. Та нарын одоо амьдарч байгаа чинь биед амьдрахын урьдач нөхцөл; энэ нь сүнсний ертөнцөд ороход шаардлагатай зам юм. Миний ярьдаг хэвийн хүн чанараас даван гарах гэдэг нь гэр бүлгүй, эхнэргүй, үр хүүхэдгүй, хүний хэрэгцээгүй байхыг хэлнэ. Энэ нь зөвхөн Миний дүр төрхийг амьдран харуулахад, зөвхөн Миний дотор ороход л төвлөрч, Надаас гаднах бусад зүйлийн тухай бодохгүй байх явдал; явсан газар бүр чинь чиний гэр билээ. Энэ бол хэвийн хүн чанарыг давж байгаа хэрэг юм. Та нар Миний энэ үгсийг туйлын буруугаар ойлгосон; та нарын ойлголт хэтэрхий өнгөц юм. Би бүх улс үндэстэн, ард түмэнд яг яаж илрэх вэ? Өнөөдөр махбодод уу? Үгүй! Цаг нь ирэхээр Би орчлон ертөнцийн бүх улс үндэстэнд Өөрийн биеэр илрэх болно. Харийнхныг та нар хариулах хэрэгтэй цаг хараахан ирээгүй байна. Тэр үед та нар тэднийг хариулахын тулд махан биеэс гарч, биед орох хэрэгтэй болно. Энэ нь үнэн боловч, хүмүүсийн төсөөлдөг “үхлээс амилж байгаа” хэрэг биш юм. Тогтсон цагт та нар өөрийн мэдэлгүй махан биеэс гарч, сүнсний ертөнцөд орж, бүх улс үндэстнийг Надтай цуг захирах болно. Цаг нь хараахан ирээгүй байна. Би та нарыг махан биед байлгах хэрэгтэй үед та нар махан биед байх болно (Миний ажлын шаардлагын дагуу, та нар одоо бодолтой байх ёстой, та нар махан биед амьдарсаар байх ёстой, иймээс та нар одоо Миний алхмын дагуу махан биед хийх ёстой зүйлсээ хийх л хэрэгтэй; идэвхгүйгээр бүү хүлээ, тэгвэл хойшлоход хүрнэ). Би та нарыг чуулганы хоньчин болгож, биед үйлдүүлэх хэрэгтэй үед, та нар махан биеэс гарч, бодол санаагаа орхиж, амьдрахын тулд Надад бүрэн найдах болно. Миний хүч чадалд итгэ, мэргэн ухаанд итгэ. Бүх зүйлийг Би биечлэн хийх болно. Та нар хүлээж байгаад эдлэх л хэрэгтэй. Бүх ерөөл та нарт очиж, дуусашгүй, эцэс төгсгөлгүй хангамж та нарынх болно. Тэр өдөр ирэхэд та нар Миний хэрхэн үүнийг хийдэг зарчмыг ойлгож, Миний гайхамшигт үйл хэргийг мэдэж, Би Өөрийн ууган хөвгүүдийг Сионд хэрхэн эргүүлж авааачдагийг ойлгох болно. Энэ үнэхээр та нарын төсөөлдөг шиг ээдрээтэй биш боловч та нарын боддог шиг энгийн ч зүйл бас биш.

Намайг ингэж хэлэхээр та нар Миний үгийн цаадах зорилгыг ойлгож бүр ч чадахгүй болж, бүр их будилдгийг Би мэднэ. Та нар эдгээрийг Миний өмнө нь хэлсэн зүйлтэй хольж хутгаад, юу ч ойлгож чадахгүй, гарах замгүй мэт санагдах болно. Гэвч бүү санаа зов. Би та нарт бүхнийг хэлнэ. Миний хэлдэг бүхэн утга учиртай. Би оршин байгаа зүйлсийг хоосон руу буцааж, оргүй хоосноос олон янзын зүйл бий болгож чадна гэж хэлсэн. Хүний төсөөллөөр бол, махан биеэс биед орохын тулд хүн үхлээс амилсан байх ёстой. Өнгөрсөнд, Би энэ аргыг ашиглан, Өөрийн хамгийн агуу гайхамшгийг үзүүлсэн ч, өнөөдөр бол өнгөрсөн үетэй адилгүй. Би та нарыг махан биеэс бие рүү шууд аваачих болно. Энэ нь бүр ч агуу тэмдэг, гайхамшиг биш гэж үү? Энэ нь Миний төгс хүчингийн илүү агуу илэрхийлэл биш гэж үү? Надад Өөрийн гэсэн төлөвлөгөө, санаа зорилго бий. Хэн Миний гарт байдаггүй вэ? Би хийдэг ажлаа мэднэ. Өнөөдөр Миний ажлын арга барил эцсийн эцэст

өнгөрсөн үеийнхээс өөр юм. Би Өөрийн ажлын арга барилыг эрин үеийн өөрчлөлтөд нийцүүлэн өөрчилдөг. Намайг загалмайд цовдлогдох үед Нигүүлслийн эрин үе байсан, харин одоо бол сүүлчийн эрин үе юм. Миний ажлын алхаа түргэсэж байна; өнгөрсөн үеийнхтэй адил хурдаар явахгүй, өнгөрсөн үеийнхээс удаашрах ч үгүй. Харин ч өнгөрсөн үеийнхээс хамаагүй хурдан явагдаж байна. Үүнийг зүгээр л үгээр илэрхийлэхийн аргагүй, үүнд тийм олон ээдрээтэй үйл явц хэрэггүй. Би юу ч хийхэд чөлөөтэй. Миний хүсэл хэрхэн гүйцэлдэж, Би та нарыг хэрхэн төгс болгохыг тодорхойлоход эрх мэдэл бүхий ганцхан л үг Надаас гарахад хангалттай гэдэг нь үнэн биш гэж үү? Миний хэлсэн бүхэн лавтай хэрэгжинэ. Өнгөрсөн үед, Би үргэлж Өөрийгөө зовно гэж хэлдэг байсан бөгөөд өмнө нь Миний туулсан зовлонг дурдахыг хүмүүст зөвшөөрдөггүй байсан; үүнийг дурдах нь Намайг доромжилсон хэрэг байлаа. Учир нь, Би бол Бурхан Өөрөө бөгөөд Надад зовлон бэрхшээл гэж үгүй; энэ зовлонг дурдах үедээ чи хүмүүсийг уйлуулдаг. Ирээдүйд санаа алдалт, нулимс гэж үгүй болно гэж Би хэлсэн. Үүнийг энэ талаас нь тайлбарлах хэрэгтэй, тэгвэл Миний үгийн утга учрыг ойлгож болно. “Хүмүүс энэ зовлонг ердөө тэвчиж чадахгүй” гэдгийн утга учир гэвэл, Би хүний бүх үзэл, бодол санаанаас хагацаж, махан биеийн бүх сэтгэл хөдлөлөөс хагацаж, хорвоогийн бүх ул мөрөөс хагацаж, махбодыг хаяж, Намайг хүн бүр няцааж байхад тэвчиж чадна. Энэ нь Би бол нэгэн Бурхан Өөрөө гэдгийг батлахад хангалттай. “Ууган хөвгүүн бүр махан биеэс сүнсний ертөнцөд орох ёстой; хаан болж Надтай хамт хаанчлахын тулд тэдний явах ёстой зам энэ” гэж Би хэлсэн. Энэ өгүүлбэр нь чи өнгөрсөн үед төсөөлсөн зүйлтэйгээ тулгарахад, та нар тэдгээр хаад, ханхүүг албан ёсоор шүүж эхлэхийн тулд албан ёсоор махан биеэс гарч, биед орно гэсэн утгатай юм. Тэд энэ үед тохиолдох зүйлсэд тулгуурлан шүүгдэх болно. Гэвч энэ нь та нарын төсөөлдөг шиг ээдрээтэй биш, хормын дотор л хийгдэх болно. Та нар үхлээс амилах хэрэггүй, та нар бүр зовох ч шаардлагагүй (учир нь та нарын газар дээрх зовлон бэрхшээл аль хэдийн эцэс болсон бөгөөд Би Өөрийн ууган хөвгүүдтэй үүнээс цааш харьцахгүй гэдгээ аль хэдийн хэлсэн). Ууган хөвгүүд хэлж байсан ёсоор ерөөлөө эдэлж, үнэндээ чи өөрийн мэдэлгүй сүнсний ертөнцөд орно. Үүнийг Би яагаад Миний өршөөл, нигүүлсэл гэдэг вэ? Хэрэв хүн үхлээс амилсны дараа л сүнсний ертөнцөд орж чаддаг сан бол, энэ нь өршөөнгүй, нигүүлсэнгүй байгаа хэрэг огт биш байх сан. Тиймээс энэ нь Миний өршөөл, нигүүлслийн хамгийн тод илэрхийлэл, түүнчлэн, энэ хүмүүсийг урьдчилан тогтоож, сонгосныг минь ил болгодог. Миний захиргааны зарлиг хэчнээн хатуу болохыг энэ хангалттай харуулж чаддаг. Би хүссэн хүн бүхэндээ нигүүлсэнгүй байж, бас хүссэн хүн бүхэндээ өршөөнгүй байх болно. Хэн ч маргаж, тэмцэх учиргүй. Би энэ бүхнийг шийдэх болно.

Хүмүүс үүний учрыг ойлгож чаддаггүй бөгөөд амьсгалж чадахгүй болтлоо өөрсдөдөө дарамт өгч, гэсэн хэр нь тэд л өөрсдийгөө хүлсээр байдаг. Хүмүүсийн бодол санаа үнэхээр хязгаарлагдмал учраас тэд хүний бодол санаа, үзлээс ангижрах ёстой. Иймээс, Би бүх зүйлийг хяналтдаа авч, бүхнийг удирдахын тулд

махбодоос гарч, сүнсний ертөнцөд орох ёстой. Энэ нь бүх ард түмэн, бүх улс үндэстнийг захирч, Миний хүслийг биелүүлэх цорын ганц арга юм. Ингэхэд холгүй байна. Та нар Миний төгс хүчинд итгэдэггүй, Миний хэн болохыг мэддэггүй. Та нар намайг ердөө хүн л гэж бодож, Миний бурханлаг чанарыг огт харж чаддаггүй. Аливаа зүйлийг Би бүрэн төгс болгохыг хүсмэгц бүрэн төгс болно. Миний амнаас үг гарахад л хангалттай. Та нар Миний ойрын үед хэлсэн зүйл, Миний үйлдэл бүр дэх Миний хүн чанарын талд л анхаарал хандуулсан боловч, Миний бурханлаг чанарын талыг анхааараагүй. Өөрөөр хэлбэл, та нар Намайг ч бас бодол санаа, үзэлтэй гэж боддог. Гэвч Миний бодол, санаа, оюун ухаан, Миний үйлдэл бүр, хийдэг бүхэн минь, бас хэлдэг бүхэн минь Бурханы Өөрийнх нь бүрэн илэрхийлэл гэж Би хэлсэн. Та нар энэ бүхнийг мартсан гэж үү? Та нар бүгд мунгинуу хүмүүс юм! Та нар Миний үгийн утга учрыг ойлгодоггүй. Би та нарт, Миний хэлсэн зүйлээс, Миний хэвийн хүн чанарын талыг харах боломж олгосон (Би та нарт, Миний өдөр тутмын амьдралаас, бодит байдал дээр Миний хэвийн хүн чанарыг харах боломж олгосон, учир нь та нар энэ хугацаанд Миний хэлсэн зүйлсээс Миний хэвийн хүн чанарын талыг ойлгоогүй л байна), гэвч та нар Миний хэвийн хүн чанарыг ойлгодоггүй, зүгээр л Миний эсрэг ашиглаж болох зүйлээс зуурч, Миний өмнө эх захгүй байдаг. Та нар сохор юм! Мэдлэггүй юм! Та нар Намайг мэддэггүй! Би их удаан хий дэмий ярьсан! Та нар Намайг огт мэддэггүй, Миний хэвийн хүн чанарыг бүрэн төгс Бурханы Өөрийнх нь нэг хэсэг гэж ердөөс үздэггүй! Би яаж уурлахгүй байж чадах юм бэ? Би яаж дахин өршөөнгүй байж чадах юм бэ? Би дуулгаваргүй энэ хүүхдүүдэд Өөрийн уур хилэнгээр л хариу барьж чадна. Та нар маш эрээ цээргүй, Намайг огт мэддэггүй! Та нар Намайг буруу зүйл хийсэн гэж боддог! Би буруу зүйл хийж болох уу? Би ямар ч хамаагүй махбодод орохоор сонгох байсан уу? Миний хүн чанар, Миний бурханлаг чанар хоёр бол бүрэн төгс Бурханыг Өөрийг нь бүрдүүлдэг салшгүй хоёр тал юм. Одоо та нар энэ талаар маш сайн ойлгох хэрэгтэй! Миний үг аль хэдийн оргилдоо хүрсэн, цаашид Миний үгийг удаан тайлбарлаж болохгүй!

99-Р БҮЛЭГ

Миний ажлын алхаа түргэсэж, хэн ч Миний алхааг гүйцэж чадахгүй, хэн ч Миний оюун ухаанд нэвтэрч чадахгүй боловч энэ бол урагшлах цорын ганц зам билээ. Энэ бол аль хэдийн ярьсан “үхлээс амилах” гэх хэллэгийн “үхсэн” (Миний хүслийг ухаарч чадахгүй, Миний үгээс юу гэж хэлж байгааг минь ойлгохгүй байхыг хэлдэг; энэ бол “үхсэн” гэдгийн өөр нэг тайлбар бөгөөд “Миний Сүнсэнд хаягдсан” гэсэн үг биш) гэдэг нь юм. Би та нарын хамт энэ үе шатнаас биед шилжсэн үед “үхлээс амилах” гэдгийн жинхэнэ утга учир биелэх болно (өөрөөр хэлбэл, энэ нь үхлээс амилахын жинхэнэ утга учир юм). Одоо, та нар бүгдээрээ оршин байгаа нөхцөл

байдал энэ: Та нар Миний хүслийг ухаарч чаддаггүй, Миний мөрийг олж чаддаггүй. Түүнчлэн, та нар сүнсээрээ тайван байж чаддаггүй учраас оюун ухаан чинь ихэд түгшдэг. Иймэрхүү нөхцөл байдал бол Миний дурдсан “зовлон” яг мөн бөгөөд хүмүүсийн тэвчиж чаддаггүй энэ зовлон дунд нэг талаар та нар өөрсдийн ирээдүйг бодож, нөгөөтээгүүр бүх талаас чинь галлаж, цохиж байгаа Миний шатаалт, шүүлтийг хүлээн авч байна. Үүнээс гадна, Миний ярианы өнгө, хэв маягаас та нар ямар ч дүрмийг ухаарч чаддаггүй, нэг өдрийн айлдварт хэд хэдэн өнгө аяс гардаг болохоор та нар ихэд зовдог. Эдгээр нь Миний ажлын алхам. Энэ бол Миний мэргэн ухаан. Ирээдүйд та нар энэ тал дээр илүү их зовлон туулах бөгөөд эдгээр нь бүгд бүх хоёр нүүртэй хүнийг илчлэхийн төлөө байдаг, одоо үүнийг тодорхой мэдэж байх ёстой! Энэ бол Миний ажилладаг арга. Иймэрхүү зовлонгоор зоригжиж, үхэлтэй эн тэнцэх энэ шаналлыг туулсныхаа дараа та нар өөр ертөнцөд орно. Та нар биед орж, Надтай хамт бүх улс үндэстэн, бүх ард түмнийг хаанчилна.

Ойрын үед, Би яагаад илүү хатуу өнгөөр ярьж байна вэ? Яагаад Миний өнгө аяс ийм ойр ойрхон солигдов, бас яагаад Миний ажиллах арга зам ийм ойр ойрхон солигдов? Миний мэргэн ухаан эдгээрт бий. Энэ нэрийг хүлээн авсан хүн бүхэнд Би үг хэлдэг (тэд Миний үгийг биелэх боломжтой гэж итгэдэг ч бай, үгүй ч бай), тиймээс Би Өөрийн гэсэн ажиллах арга, мэргэн ухаантай тул Миний үг дарагдалгүй, хүн болгонд харагдаж, сонсогдох учиртай. Би хүмүүсийг шүүж, илчилж, мөн хүний уг чанарыг ил болгохын тулд Өөрийн үгийг ашигладаг. Ингэж Би Өөрийн шилж авсан хүмүүсийг сонгож, Өөрийн урьдчилан тогтоож, сонгоогүй хүмүүсийг таягдан хаядаг. Энэ бүхэн Миний мэргэн ухаан, мөн Миний ажлын гайхамшиг юм. Энэ бол Миний ажлын энэ үе шатан дахь Миний арга барил юм. Хүмүүсийн дунд Миний хүслийг ухаарч чаддаг хүн байна уу? Хүмүүсийн дунд Миний ачаанд санаа тавьж чадах хүн байна уу? Ажил хийж байгаа Нэгэн бол Би, Бурхан Өөрөө юм. Та нар Миний эдгээр үгийн ач холбогдлыг нэгд нэгэнгүй ойлгох өдөр ирнэ, тэгээд та нар Би яагаад эдгээр үгийг хэлэхийг хүссэнийг бүрэн ойлгох болно. Миний мэргэн ухаан төгсгөлгүй, хязгааргүй, хэмжишгүй, бас хүмүүсийн хувьд бүрэн нэвтэршгүй байдаг. Хүмүүс Миний хийдэг зүйлсээс үүний ердөө нэгээхэн хэсгийг харж чаддаг боловч, тэдний хардаг зүйл бас л дутагдалтай, дутуу дулимаг байдаг. Та нар энэ үе шатнаас дараагийн үе шатанд бүрэн шилжсэн үедээ, үүнийг тодорхой харж чадна. Санаж яв! Одоо бол хамгийн үнэ цэнтэй эрин үе—энэ бол та нарын махан биед байх эцсийн үе шат. Одоогийн амьдрал чинь та нарын биет амьдралын сүүлийнх нь. Та нар махан биеэс сүнсний ертөнцөд ороход, тэр үед бүх өвчин шаналал та нарыг орхих болно. Та нар ихэд баясан хөөрч, баярласандаа зогсолтгүй дэвхцэх болно. Гэхдээ ууган хөвгүүд л энэ ерөөлийг хүртэх гавьяатай тул, Миний хэлж байгаа үг зөвхөн ууган хөвгүүдэд зориулагдсан гэдгийг та нар тодорхой ойлгох ёстой. Сүнсний ертөнцөд орно гэдэг хамгийн агуу, хамгийн дээд ерөөл бөгөөд эдлэх хамгийн үнэтэй зүйл юм. Одоо та нарын идэж, өмсөхөөр олж авдаг зүйлс бол махан биеийн таашаалаас цаашгүй; тэдгээр нь нигүүлсэл бөгөөд Би тэдгээрийг

огтоос ойшоодоггүй. Миний ажил дараагийн үе шатанд төвлөрч байна (сүнсний ертөнцөд орж, орчлон ертөнцтэй нүүр тулах).

Би агуу улаан лууг аль хэдийн шидэж унаган, бяц дарсан гэдгээ хэлсэн. Та нар яаж Миний үгэнд итгэхгүй байж чадна вэ? Яагаад та нар Миний төлөө хавчлага, бэрхшээл туулахыг хүссээр байна вэ? Энэ чинь төлөх шаардлагагүй төлөөс бус уу? Намайг ажлаа Өөрөө биечлэн хийж байхад, та нар таашаахад л болно гэж Би олон удаа та нарт сануулсан. Яагаад та нар үйлдэл хийхэд тэгтлээ дурлана вэ? Та нар үнэхээр яаж таашаахаа мэддэггүй юм байна! Би та нарт бүх зүйлийг бүрэн бэлдсэн—яагаад та нарын хэн нь ч үүнийг авахаар Над дээр ирээгүй юм бэ? Та нар Миний хэлсэн зүйлийн талаар одоо ч итгэлтэй биш байна! Та нар Намайг ойлгодоггүй! Та нар Намайг хоосон гоё үг ярьж байна гэж боддог; та нар үнэхээр мунгинуу юм! (Миний ярьж байгаа бүрэн бэлтгэл гэдэг нь та нар Намайг илүү их хүндэлж, Миний өмнө улам их залбирах ёстой, харин Намайг эсэргүүцдэг хүн бүрийг харааж, та нарыг хяхаж хавчдаг хүн болгоныг шийтгэхээр Би биечлэн ажиллах болно гэсэн үг юм.) Та нар Миний үгийн тухай юу ч мэддэггүй! Би та нарт Өөрийн бүх нууцыг илчилж байхад, та нараас хэд нь үүнийг үнэхээр ойлгодог билээ? Хэд нь үүнийг гүн гүнзгий ойлгодог вэ? Миний сэнтий гэж юу вэ? Миний төмөр саваа гэж юу вэ? Та нарын дундаас хэн чинь мэдэх вэ? Миний сэнтийг дурдах үед ихэнх хүн үүнийг Миний суудаг газар, Миний амьдран суудаг газар, эсвэл Намайг, Миний үнэн биеийг хэлж байна гэж боддог. Эдгээр нь бүгд ташаа ойлголт, ердөө жонхуурсан буруу ойлголт юм! Эдгээр тайлбарын аль нь ч зөв биш, тийм биз дээ? Та нар бүгд үүнийг ийм байдлаар ойлгож, ухаардаг—энэ нь ердөө л туйлын гажууд ойлголт юм! Эрх мэдэл гэж юу вэ? Эрх мэдэл, сэнтий хоёр хоорондоо ямар холбоотой вэ? Сэнтий бол Миний эрх мэдэл юм. Миний ууган хөвгүүд Миний сэнтийг өндөрт өргөх үе бол Миний ууган хөвгүүд Надаас эрх мэдэл хүлээн авах цаг үе юм. Зөвхөн Надад эрх мэдэл бий, тиймээс зөвхөн Надад сэнтий бий. Өөрөөр хэлбэл, Миний ууган хөвгүүд Намайг зовсонтой адилаар зовсны дараа Би юу болох, Надад юу байгааг хүлээн авч, Надаас бүхнийг хүлээн авах болно; энэ үйл явцаар тэд ууган хөвгүүний байр суурийг олж авна. Энэ нь Миний ууган хөвгүүд Миний сэнтийг өндөрт өргөх үе, мөн тэд Надаас эрх мэдлийг хүлээн авах үе байх болно. Одоо үүнийг ойлгох хэрэгтэй! Хүн бүрд ойлгуулахын тулд Миний хэлдэг бүхэн тодорхой, ямар ч хоёрдмол утгагүй байдаг. Өөрсдийн үзлийг хойш тавьж, Миний та нарт илчлэх нууцыг хүлээн авахаар хүлээ! Тэгвэл, төмөр саваа гэж юу вэ? Өмнөх үе шатанд, энэ нь Миний хатуу үгийг хэлж байсан бол одоо энэ нь өнгөрсөн үеэс өөр: Одоо төмөр саваа нь Миний үйл хэрэг буюу эрх мэдлийг шингээсэн агуу гамшгийг хэлж байна. Тиймээс төмөр сабааг дурдах болгонд үргэлж эрх мэдэлтэй холбоотой байдаг. Төмөр сабааны анхны утга нь агуу гамшгийг хэлдэг—энэ нь эрх мэдлийн нэг хэсэг юм. Хүн бүр үүнийг тодорхой харах ёстой, тэгж байж л тэд Миний хүслийг ухаарч, Миний үгээс илчлэл хүлээн авах болно. Ариун Сүнсний ажил байгаа хэн боловч гартаа төмөр саваа атгадаг бөгөөд тэр хүн

эрх мэдлийг атгаж, аль ч агуу гамшгийг хэрэгжүүлэх эрхтэй байдаг. Энэ нь Миний захиргааны зарлигийн нэг юм.

Юм болгон, бүх зүйл та нарт нээлттэй (энэ нь тодорхой хэлж өгсөн хэсгийг хэлж байна), юм болгон, бүх зүйл та нараас далд (энэ нь Миний үгийн нууц хэсгийг хэлж байна) байдаг. Би мэргэн ухаанаар ярьдаг: Би та нарт Өөрийн зарим үгийн шууд утгыг л ойлгуулж, харин заримынх нь утга учрыг нь ухааруулдаг (гэхдээ ихэнх хүн ойлгож чаддаггүй), учир нь энэ бол Миний ажлын дараалал юм. Би та нарыг тодорхой биеийн хэмжээтэй болсон цагт л Өөрийн үгийн жинхэнэ утгыг та нарт хэлж чадна. Энэ бол Миний мэргэн ухаан, эдгээр нь Миний гайхамшигт үйл хэрэг (та нарыг төгс болгож, Сатаныг бүрмөсөн ялж, диаволуудыг шившиглэхийн төлөөх). Та нар өөр ертөнцөд ортлоо бүрэн ойлгож чадахгүй. Хүний үзэлд хүмүүсийн ердөө ч ойлгож чаддаггүй олон зүйл байдаг учир, Би үүнийг ийм маягаар хийх ёстой, хэдий Би тодорхой хэллээ ч, та нар ойлгохгүй хэвээр л байх нь тодорхой. Эцсийн эцэст, хүмүүсийн оюун ухаан хэмжээ хязгаартай бөгөөд та нарыг зөвхөн сүнсний ертөнцөд орсны чинь дараа л Би хэлж чадах олон зүйл бий; эс бөгөөс, хүний махан бие бэлэн биш байдаг нь Миний удирдлагад саад л хийнэ. Энэ бол Миний ярьдаг “Миний ажлын дараалал” гэдгийн жинхэнэ утга учир юм. Та нар үзлээрээ Намайг хэр их ойлгодог вэ? Та нарын ойлголт өө сэвгүй юу? Мэдлэг сүнсэнд байдаг уу? Иймээс, та нар Миний ажлыг гүйцэлдүүлж, Миний хүслийг биелүүлэхийн тулд, Би та нарыг өөр ертөнц рүү шилжүүлэх ёстой. Тэгвэл энэхүү өөр ертөнц гэж яг юу вэ? Энэ үнэхээр хүмүүсийн боддог шиг ер бусын үзэгдэл үү? Энэ үнэхээр харагдаж, мэдрэгддэггүй атлаа оршин байдаг агаар мэт зүйл үү? Миний хэлсэнчлэн, биед байх байдал бол мах, ястай, мөн хэлбэр, дүрстэй байх явдал юм. Энэ бол туйлаас үнэн, маргаангүй бөгөөд хүн бүр үүнд итгэх ёстой. Энэ бол бие дэх бодит байдал юм. Түүнчлэн, хүмүүсийн үзэн яддаг нэг ч юм биед байдаггүй. Гэхдээ энэхүү байдал нь яг юу юм бэ? Хүмүүс махбодоос биед шилжихэд томоохон бүлэг гарч ирэх ёстой. Өөрөөр хэлбэл, тэд өөрсдийн махан биеийн гэрээс ангижрах бөгөөд дор бүрнээ өөрийн төрлийг дагана гэж хэлж болно: Махан бие нь махан биедээ цугларч, бие нь биедээ цугладаг. Одоо гэр орон, эцэг эх, эхнэр нөхөр, хүү, охиноосоо ангижирдаг хүмүүс сүнсний ертөнцөд орж эхэлдэг. Эцэстээ иймэрхүү байдалтай байдаг: Сүнсний ертөнц дэх нөхцөл байдал гэвэл ууган хөвгүүд хамтдаа цуглараад, дуулж, бүжиглэн, Миний ариун нэрийг магтаж, уухайлдаг. Энэ бол үзэсгэлэнтэй, үргэлжийн шинэ дүр зураг юм. Бүгд Намайг үүрд зогсолтгүй магтаж, Миний ариун нэрийг үүрд дээш өргөдөг Миний хайртай хөвгүүд байдаг. Энэ бол сүнсний ертөнцөд орсны дараах нөхцөл байдал, сүнсний ертөнцөд орсны дараах ажил, мөн сүнсний ертөнцөд чуулганыг хариулах тухай Миний ярьсан нөхцөл байдал юм. Түүнчлэн, энэ нь орчлон ертөнцийн үндэстэн бүрд, мөн бүх үндэстэн, бүх ард түмний дунд бүх үндэстэн, бүх ард түмнийг захирахаар Миний эрх мэдэл, Миний уур хилэн, Миний шүүлт болон бүр илүүтэйгээр Миний төмөр сабааг барин гарч ирдэг Миний үнэн бие билээ. Энэ нь бүх ард түмний дунд,

бүхий л орчлон ертөнцөд тэнгэр, газрыг доргиодог Надад гэрчлэл хийж, бүх ард түмэн, уул ус, гол мөрөн, нуур болон газар дэлхийн зах хязгаар дахь бүх зүйлийг Намайг магтаж, Намайг алдаршуулж, Намайг мэдэхэд хүргэдэг ба бүхнийг залж чиглүүлж, бүхнийг удирдаж, шүүж, гүйцэлдүүлж, шийтгэж, сөнөөдөг бүх зүйлийг Бүтээгч, цор ганц Бурхан Өөрөө бол Миний үнэн биеийн жинхэнэ илрэлт юм.

100-Р БҮЛЭГ

Би Өөрөө урьдчилан тогтоож, сонгоогүй бүх хүнийг үзэн яддаг. Ийм учраас, Би энэ хүмүүсийг Өөрийн гэрээс нэг нэгээр нь явуулах ёстой бөгөөд тэгж байж Миний сүм ариун, бузарлагдаагүй, Миний гэр үргэлж шинэ, хэзээ ч хуучрахгүй байж, Миний ариун нэр үүрд түгж, Миний ариун хүмүүс Миний хайртай хүмүүс болох болно. Ийм дүр зураг, ийм гэр, ийм хаанчлал бол Миний зорилго, Миний орон гэр; энэ бол Миний бүх зүйлийг бүтээсэн суурь юм. Хэн ч үүнийг ганхуулж эсвэл өөрчилж үл болно. Энд зөвхөн Би хайрт хөвгүүдийнхээ хамт амьдарна, үүнийг уландаа гишгэлэхийг хэнд ч зөвшөөрөхгүй, үүнийг эзэгнэхийг юунд ч зөвшөөрөхгүй, ямарваа таагүй зүйл тохиолдохыг бүр ч зөвшөөрөхгүй. Бүгд магтаал, уухай байх ба бүгд хүний төсөөлөхийн аргагүй дүр зураг байх болно. Та нарыг бүх хүчээ бүхий л зүрх сэтгэл, оюун санааныхаа хамтаар чадлынхаа хэрээр Надад өргөөсэй л гэж Би хүсдэг. Өнөөдөр ч бай, маргааш ч бай, Надад үйлчлэл үзүүлдэг ч бай, Надаас ерөөл хүртдэг ч бай та нар бүгдээрээ хүч чадлынхаа нэгээхэн хэсгийг Миний хаанчлалын төлөө гаргах хэрэгтэй. Энэ бол бүтээгдсэн бүх хүний хүлээх ёстой үүрэг бөгөөд үүнийг ингэж биелүүлж, хэрэгжүүлэх ёстой юм. Өөрийн хаанчлалын гоо үзэсгэлэнг мөнхөд шинэ байлгаж, Өөрийн гэрийг эв найртай, нэгдмэл болгохын төлөө үйлчлэл хийлгэхэд Би бүх зүйлийг дайчилна. Намайг сөрж эсэргүүцэхийг хэнд ч зөвшөөрөхгүй бөгөөд эсэргүүцсэн бүхэн шүүлт амсаж, хараагдах ёстой. Одоо Миний хараал бүх улс үндэстэн, бүх хүн дээр бууж эхэлнэ, Миний хараал Миний шүүлтээс хавьгүй илүү хатуу билээ. Бүх хүнийг яллаж эхлэх цаг одоо ирсэн болохоор үүнийг хараал гэдэг. Учир нь, одоо бол бүтээлийн цаг үе биш, эцсийн эрин үе билээ. Эрин үеүд ээлжлэхийн хэрээр Миний ажлын хурд ч одоо маш ондоо болсон. Миний ажлын шаардлагын улмаас Надад хэрэгтэй хүмүүс ч бас өөр өөр; орхих хэрэгтэй хүмүүсийг орхино; тасдаж хаях хэрэгтэй хүмүүсийг тасдаж хаяна; алах хэрэгтэй хүмүүсийг алж, үлдээх хэрэгтэй хүмүүсийг үлдээх ёстой. Энэ бол хүний хүслээс үл хамаарах зайлшгүй чиг хандлага бөгөөд ямар ч хүн үүнийг өөрчилж үл болно. Миний хүслийн дагуу үүнийг хийх ёстой! Би хаяхыг хүссэн хүмүүсээ хаяж, таягдахыг хүссэн хүмүүсээ таягдан хаяна; хэн ч дур зоргоороо авирлахгүй. Би үлдээхийг хүссэн хүмүүсээ үлдээж, мөн хайрлахыг хүссэн хүмүүсээ хайрлана; Миний хүслийн дагуу үүнийг хийх ёстой! Би сэтгэл хөдлөлөөр юмыг хийдэггүй; Надад гагцхүү зөвт байдал, шүүлт, уур хилэн л байдаг—сэтгэл хөдлөл

огт байхгүй. Надад хүний ул мөр өчүүхэн ч байдаггүй, учир нь Би бол Бурхан Өөрөө, Бурханы үнэн бие билээ. Хүмүүс бүгд хүн чанарын талыг минь хараад Миний бурханлаг чанарын талыг хараагүй болохоор тэд үнэхээр сохор агаад мунгинуу!

Миний хэлсэн зүйлийг та нар зүрх сэтгэлдээ хадгалж, Миний үгээс Миний зүрх сэтгэлийг ойлгож, Миний ачаанд санаа тавих ёстой. Тэгвэл та нар Миний төгс хүчийг мэдэж авч, Миний үнэн биеийг харна. Учир нь, Миний үг бол мэргэн ухааны үг, хэн ч Миний үгийн цаад зарчим буюу хуулийг ойлгож чадахгүй. Хүмүүс Намайг заль мэх болон шударга бус занг хэрэгжүүлдэг хэмээн бодож, Миний үгээр дамжуулж Намайг танихын оронд харин ч Намайг доромжилдог. Тэд үнэхээр сохор агаад мунхаг! Тэдэнд ялган таних чадвар өчүүхэн ч үгүй. Миний айлдсан өгүүлбэр бүхэн эрх мэдэл, шүүлт агуулдаг агаад Миний үгийг хэн ч өөрчилж чадахгүй. Би үгээ хэлэхэд аливаа зүйл Миний үгийн дагуу биелэгдэх нь гарцаагүй; энэ бол Миний зан чанар юм. Миний үг бол эрх мэдэл, Миний үгийг засварладаг хэн боловч Миний гэсгээлтийг зөрчиж буй хэрэг бөгөөд Би тэднийг цохин унагаах ёстой. Ноцтой тохиолдолд тэд өөрсдийн аминд сүйрэл авчирч, Үхэгсдийн орон руу явах буюу ёроолгүй нүхэнд унадаг. Хүн төрөлхтөнтэй Би ингэж л харьцдаг, хүн үүнийг өөрчлөх аргагүй—энэ бол Миний захиргааны зарлиг. Үүнийг санаж яв! Миний зарлигийг зөрчихийг хэнд ч зөвшөөрөхгүй; Миний хүслийн дагуу аливааг хийх ёстой! Өмнө нь Би та нарт хэтэрхий зөөлөн байж, та нар зөвхөн Миний үгтэй л таарч байсан. Хүмүүсийг цохиж унагаах тухай Миний хэлсэн үг хараахан биелээгүй байна. Гэхдээ Миний хүслийг дагадаггүй хүмүүсийг шийтгэхээр бүх гай гамшиг (Миний захиргааны зарлигийн дагуу) өнөөдрөөс эхлэн ар араасаа ирнэ. Бодит баримтууд гарч ирэх ёстой, эс бөгөөс хүмүүс Миний уур хилэнг харж чадахгүй, ахин дахин самуурах болно. Миний удирдлагын төлөвлөгөөний нэг алхам нь энэ бөгөөд ажлынхаа дараагийн алхмыг Би ингэж хийдэг. Зөрчил гаргах, мөхлийн зовлонг үүрд туулахаас зайлсхийж чадаасай гэсэндээ Би та нарт үүнийг урьдчилан хэлж байна. Өөрөөр хэлбэл, өнөөдрөөс эхлэн Би Өөрийн ууган хөвгүүдээс бусад бүх хүнийг Өөрийн хүслийн дагуу зохих байранд нь тавьж, нэг нэгээр нь гэсгээх болно. Би нэгийг нь ч зүгээр өнгөрөөхгүй. Та нар дахиж завхраад үзээрэй! Та нар дахиж тэрслээд үзээрэй! Би бүгдэд нь зөвт байдаг, Надад уян сэтгэл өчүүхэн ч үгүй гэдгийг Би өмнө нь хэлсэн бөгөөд Миний зан чанарт халдах ёсгүйг энэ нь харуулдаг. Энэ бол Миний үнэн бие. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Бүх хүн Миний үгийг сонсож, бүх хүн Миний суу алдарт дүр төрхийг хардаг. Бүх хүн Надад бүрэн дүүрэн, туйлын дуулгавартай байх ёстой—энэ бол Миний захиргааны зарлиг юм. Орчлон ертөнц даяарх, хорвоогийн хязгаарт буй бүх хүн Намайг магтан алдаршуулах хэрэгтэй, учир нь Би бол цор ганц Бурхан Өөрөө, Би бол Бурханы үнэн бие билээ. Миний үг, айлдварууд болон Миний яриа, зан байдлыг хэн ч өөрчилж чадахгүй, учир нь эдгээр нь ганцхан Миний хувьд чухал, эдгээр нь эртнээс нааш Надад байсан бөгөөд үүрд орших болно.

Хүмүүс Намайг турших санаа зорилго өвөрлөдөг бөгөөд Намайг гутаахын тулд

Миний эсрэг ашиглаж болох зүйлсийг Миний үгэн дотроос олохыг хүсдэг. Чи Намайг гутаах хэрэг үү? Намайг тоомжиргүй шүүх хэрэг үү? Миний ажил хэргийг тоомжиргүй хэлэлцэх хэрэг үү? Та нар үнэхээр өөрсдөдөө юу тустайг мэддэггүй хүмүүс юм! Та нар Намайг огт мэддэггүй юм байна! Сион уул гэж юу вэ? Миний орон гэр гэж юу вэ? Канааны сайн газар гэж юу вэ? Бүтээлийн суурь нь юу вэ? Яагаад сүүлийн хэдэн өдөр Би эдгээр үгийг дурдсаар байгаа юм бэ? Сион уул, Миний орон гэр, Канааны сайн газар, бүтээлийн суурь, энэ бүгдийг Миний үнэн биетэй холбогдуулан (биетэй холбогдуулан) хэлсэн. Хүмүүс бүгдээрээ эдгээрийг бодитоор оршдог газар гэж боддог. Миний үнэн бие бол Сион уул; энэ бол Миний орон гэр юм. Сүнсний ертөнцөд орсон хэн боловч Сион ууланд авирч, Миний орон гэрт орно. Би бүх зүйлийг үнэн бие дотроо бүтээсэн; өөрөөр хэлбэл, бүх зүйлийг биеийн дотор бүтээсэн болохоор энэ нь суурь юм. Та нар Надтай хамт биед эргэн ирнэ гэж Би яагаад хэлдэг вэ? Жинхэнэ утга нь энд бий. Яг л “Бурхан” гэдэг нэршилтэй адил, эдгээр нэр үг нь дангаараа ямар ч утгагүй, харин өөр өөр газруудад Миний өгсөн өөр өөр нэр юм. Иймд үгчилсэн утгад нь нэг их анхааралгүй Миний үгийг сонсоход л анхаарлаа төвлөрүүл. Та нар тэдгээрийг ингэж харах ёстой, тэгж байж Миний хүслийг ойлгож чадна. Миний үгэнд мэргэн ухаан бий гэж Би та нарт яагаад дахин дахин сануулдаг вэ? Та нараас хэд нь үүний цаад утгыг ойлгох гэж оролдсон бэ? Та нар бүгд сохроор шинжилж байгаа бөгөөд ухаангүй байна!

Урьд өмнө Миний хэлсэн зүйлсийн ихэнхийг нь та нар одоо ч гэсэн ойлгохгүй л байна. Та нар эргэлзсэн хэвээр байж, Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чаддаггүй. Миний айлдсан өгүүлбэр бүрд итгэлтэй байж чаддаг болсон тэр цаг үе та нарын амь боловсрох агшин байх болно. Надад нэг өдөр бол мянган жил шиг, мянган жил бол нэг өдөр шиг; та нар Миний ярьдаг цаг хугацааны талаар юу гэж бодож байна? Та нар үүнийг яаж тайлбарлах вэ? Та нар буруу тайлбарладаг! Мөн түүнчлэн, ихэнх хүн үүний талаар Надтай маргаж, Миний эсрэг ашиглах зүйл олохыг хүсдэг—өөртөө юу тустайг чи мэддэггүй! Болгоомжтой бай, эс бөгөөс Би чамайг цохиж унагаана! Бүх зүйл тодорхой болох өдөр ирэхэд та нар бүрэн ухаарна. Би та нарт одоо ч хэлдэггүй (одоо бол хүмүүсийг ил болгох цаг; Миний хүслийг хангаж чадахын тулд хүн бүр болгоомжтой, сэрэмжтэй байх ёстой). Би үгээрээ бүх хүнийг ил болгож, төрөлх дүрийг нь илчилж, жинхэнэ эсэхийг нь харуулна. Хэрвээ хэн нэгэн янхан эсвэл иезебел бол Би тэднийг ил болгох ёстой. Би аливааг хуруугаа ч хөдөлгөлгүйгээр хийдэг бөгөөд зөвхөн үгээрээ хүмүүсийг ил болгодог гэдгээ Би өмнө нь хэлсэн. Би ямар ч зүс хувиргалтаас айдаггүй; Би үгээ айлдмагц чи төрөлх дүрээ илчлэх ёстой бөгөөд зүсээ хэчнээн сайн хувиргасан ч Би гарцаагүй нэвт харна. Ямар ч хүч зарлагадалгүй, зөвхөн айлдвар л ашиглах нь Миний үйл хэргийн зарчим юм. Миний үг биелэгдэх эсэх талаар хүмүүс ихэд бачимдаж, Миний төлөө сэтгэл түгшиж, Надад санаа зовдог, гэвч ийм хүчин чармайлт үнэндээ шаардлагагүй; эдгээр нь төлөх хэрэггүй төлөөс юм. Чи Миний талаар санаа зовоод байх юм, гэтэл өөрийн чинь амь боловсорсон бил үү? Чиний

хувь тавилан ямар билээ? Үүнийг өөрөөсөө байнга асуу, салан задгай бүү бай. Хүмүүс бүгд Миний ажлыг анхааралдаа авч, Миний үйл хэрэг болон Миний үгээр дамжуулан Миний үнэн биеийг харж, Миний талаар үлэмж мэдлэгтэй болж, Миний төгс хүч, Миний мэргэн ухааныг мэдэж, бүх зүйлийг бүтээсэн Миний арга барил, аргачлалыг мэдэж, тэгснээр Надад дуусашгүй магтаал өгөх ёстой. Миний захиргааны зарлиг хэнд хамаардаг, Би хэн дээр ажилладаг, Би юу хийхийг хүсдэг, мөн Би юу гүйцэлдүүлэхийг хүсдэг гэдгээ Би бүх хүнд харуулна. Энэ бол хүн бүрийн биелүүлэх ёстой зүйл, учир нь энэ бол Миний захиргааны зарлиг билээ. Би хэлснээ гүйцэлдүүлнэ. Хэн ч Миний үгийг тоомжиргүй задлан шинжлэх ёсгүй; Миний үгээс Миний үйл хэргийн цаад зарчмыг харж, Миний үгээс Миний уур хилэн юу болохыг, Миний хараал юу болохыг, Миний шүүлт юу болохыг бүгд мэдэх ёстой. Эдгээр зүйл бүгд Миний үгээс хамаардаг бөгөөд Миний үг нэг бүрээс хүн нэг бүрийн харах ёстой зүйл энэ юм.

101-Р БҮЛЭГ

Миний удирдлагад саад болдог, Миний төлөвлөгөөг сүйтгэхийг хичээдэг хэнд ч Би өчүүхэн төдий ч өршөөнгүй хандахгүй. Хүн бүр, Миний юу гэх гээд байгааг айлддаг үгээс минь ухаарч, Миний ярьж байгаа зүйлийн талаар тодорхой ойлголттой байх ёстой. Одоогийн нөхцөл байдлаас үзэхэд, та нар дор бүрнээ өөрсдийгөө шинжлэх ёстой: Та нар ямар төрлийн үүрэг гүйцэтгэж байна вэ? Та нар Миний төлөө амьдарч байна уу, эсвэл Сатанд үйлчлэл хийж байна уу? Чиний үйлдэл бүр Надаас үүсэн гардаг уу, эсвэл диаволоос уу? Миний захиргааны зарлигийг зөрчиж, улмаар Миний дүрэлзэх уур хилэнг хүргэхээс зайлсхийхийн тулд та нар энэ бүгдийн талаар сайн ойлгосон байх ёстой. Өнгөрснийг эргээд харахад, хүмүүс үргэлж Надад үнэнч бус, ачлалгүй байсан; Намайг хүндлэхгүйгээр зогсохгүй, Надаас урвасан. Ийм шалтгаануудын улмаас энэ хүмүүс өнөөдөр Миний шүүлттэй нүүр тулдаг. Хэдийгээр Би ердөө л хүн шиг харагдаж байгаа ч Миний сайшаадаггүй хүмүүс (чи үүнээс Миний юу гэх гээд байгааг ойлгох хэрэгтэй: Чи хэчнээн үзэсгэлэнтэй, эсвэл хэчнээн сэтгэл татам харагдах нь чухал биш, харин чамайг Би урьдчилан тогтоож, сонгосон уу гэдэг нь чухал) Надад таягдуулан хаягдах болно. Энэ бол гарцаагүй үнэн. Учир нь, Би гаднаа хүн шиг харагдаж болох ч, Миний бурханлаг чанарыг ухамсарлахын тулд чи Миний хүн чанарыг давж харах шаардлагатай. Би, “Хэвийн хүн чанар болон бүрэн төгс бурханлаг чанар нь бүрэн төгс Бурханы Өөрийнх нь салшгүй хоёр хэсэг юм” гэж олон удаа хэлсэн. Гэсэн хэдий ч, та нар Намайг ойлгохгүй байсаар; өөрийнхөө тодорхой бус Бурханд л чухал ач холбогдол өгдөг. Та нар бол сүнслэг хэрэг явдлыг ойлгодоггүй хүмүүс. Гэлээ ч ийм хүмүүс Миний ууган хөвгүүд болохыг хүссээр байдаг. Ямар ичгүүргүй юм бэ! Тэд өөрсдийнх нь байр суурь үнэхээр ямар болохыг хардаггүй! Миний ардуудын үүрэг гүйцэтгэх байр

суурь ч байхгүй байж, яаж Миний ууган хөвгүүд болж, Надтай хамт хаан болж чадах юм бэ? Ийм хүмүүс өөрсдийгөө мэддэггүй; тэд бол Сатаны төрлийнхөн, Миний гэрийн багана байх нь байтугай Миний өмнө үйлчлэх ч гавьяагүй. Иймд, Би тэднийг нэг нэгээр нь таягдан хаяж, нэг нэгээр нь үнэн төрхийг нь илчилнэ.

Миний ажил ямар ч саад тотгор, өчүүхэн ч барцадгүйгээр алхам алхмаар урагшилдаг, учир нь Би ялалтыг олж авч, бүх орчлон ертөнц даяар Хаан болж хаанчилсан. (Диавол Сатаныг ялсны дараа Би хүчээ дахин шинээр эргүүлэн авсныг хэлж байна.) Би ууган хөвгүүдээ бүгдийг нь олж авахад ялалтын туг Сион уулан дээр мандах болно. Өөрөөр хэлбэл, Миний ууган хөвгүүд бол Миний ялалтын туг, Миний алдар суу, Миний сайрхдаг зүйл билээ; тэд бол Би Сатаныг шившиглэсний тэмдэг, тэд бол Миний ажилладаг арга барил юм. (Намайг урьдчилан тогтоосны дараа Сатан завхруулсан ч Миний талд дахин эргэж ирсэн бүлэг хүнээр дамжуулан Би агуу улаан лууг шившиглэж, бүх тэрслүү хөвгүүнийг захирдаг.) Миний төгс хүчин оршдог газар Миний ууган хөвгүүд байдаг; тэд бол Миний агуу амжилт, өөрчлөгдөшгүй агаад маргаангүй юм. Тэднээр дамжуулан Би удирдлагын төлөвлөгөөгөө гүйцэлдүүлнэ. “Та нараар дамжуулан Би бүх улс үндэстэн болон бүх хүнийг Өөрийн сэнтийн өмнө эргэн ирүүлнэ” гэж өмнө нь хэлсэн минь ийм утгатай. “Та нарын мөрөн дээрх хүнд ачаа” гэх үгийг хэлэхдээ мөн Би үүнийг хэлсэн билээ. Ойлгомжтой юу? Та нар ойлгож байна уу? Ууган хөвгүүд бол Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний биежилт юм; энэ шалтгааны улмаас Би энэ бүлэг хүмүүст хэзээ ч зөөлөн хандаж байгаагүй, тэднийг үргэлж хатуу чандаар сахилгажуулж байсан (тэрхүү хатуу сахилгажуулалт нь энэ дэлхийд амсдаг зовлон зүдүүр, гэр бүлийн золгүй явдал, эцэг эх, нөхөр, эхнэр, үр хүүхдэдээ хаягдах явдал—товчоор хэлбэл, дэлхийд орхигдож, энэ эрин үед хаягдах явдал юм.), ийм учраас та нарт өнөөдөр Миний өмнө ирэх сайн заяа төөрөг байдаг. Энэ бол та нарын байнга бодож байсан “Яагаад бусад хүн энэ нэрийг хүлээн аваагүй байхад Би хүлээн авсан хэрэг вэ?” гэсэн асуултын хариу. Та нар одоо мэдлээ!

Өнөөдөр юу ч өнгөрсөнтэй ижил биш. Миний удирдлагын төлөвлөгөө шинэ арга барилтай болж, Миний ажил өмнөхөөсөө бүр ч их өөрчлөгдөж, одоо Миний айлдварууд урьд хожид бүр ч илүү үзэгдэж харагдаагүй. Тиймээс, та нар Надад зохих ёсоор үйлчлэл үзүүлэх хэрэгтэй гэж Би ахин дахин онцолсон (үүнийг үйлчлэл үзүүлэгчдэд хэлсэн). Өөрсдөдөө сөргөөр бүү ханд, харин чин сэтгэлийн эрэлхийлэлтэй бай. Нигүүлсэл олж авах нь таатай биш гэж үү? Дэлхий дээр зовсноос хамаагүй дээр. Би чамд хэлье! Хэрэв чи Надад чин сэтгэлээсээ үйлчлэл үзүүлэхийн оронд, Намайг зөвт бус байлаа хэмээн гомдоллох аваас маргааш чи Үхэгсдийн орон болон там руу унана. Ямар ч хүн эрт үхэхийг хүсдэггүй, тийм биш гэж үү? Амьдралын дахиад нэг өдөр ч гэсэн, чухал өдөр байх учраас Миний удирдлагын төлөвлөгөөнд өөрийгөө бүхэлд нь өргөн барьж, дараа нь чамайг шүүхийг минь, Миний зөвт гэсгээлт чамд дээр буухыг хүлээ. Намайг утгагүй зүйл хэлж байна гэж бүү бод; Би Өөрийн зөвт байдал, Өөрийн зан чанараас ярьж байна.

Түүнчлэн, Би Өөрийн сүр жавхлан болон зөвт байдлаар үйлддэг. Хүмүүс бүгдээрээ Намайг зөвт биш гэж хэлдэг нь Намайг мэддэггүй учраас тэр юм; энэ бол тэдний тэрслүү зан чанарын тодорхой илрэл билээ. Надад сэтгэл хөдлөл байхгүй; харин зөвхөн зөвт байдал, сүр жавхлан, шүүлт болон уур хилэн л бий. Цаг хугацаа явах тусам, та нар Миний зан чанарыг улам их харах болно. Одоо цаг бол шилжилтийн үе бөгөөд та нар үүний өчүүхэн хэсгийг л харж чаддаг; та нар зарим нэг гаднаа илэрсэн зүйлсийг л харж чадна. Миний ууган хөвгүүд гарч ирэхэд, Би та нарт бүхнийг харж, бүхнийг ойлгох боломж олгоно. Хүн бүр зүрх сэтгэлдээ болон үг хэлээрээ үнэмшинэ. Би та нараар Өөрийгөө ил тодоор гэрчлүүлж, үүрд Өөрийгөө магтуулж, үүрд Өөрийгөө өргөмжлүүлнэ. Энэ нь зайлшгүй бөгөөд хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Хүмүүс үүнд итгэх нь бүү хэл, төсөөлж ч чаддаггүй.

Ууган хөвгүүд болох хүмүүс үзэгдлийн талаар улам илүү тодорхой мэддэг, Намайг гэсэн тэдний хайр бүр ч ихээр нэмэгддэг. (Энэ бол Намайг уруу татах Сатаны уруу таталт, заавал нэвт харах ёстой янаг амрагийн хайр биш. Ийм шалтгаанаар өмнө нь Би, Миний өмнө сэтгэл татам байдлаа гайхуулдаг хүмүүс байдгийг дурдсан. Ийм хүмүүс бол Намайг өөрсдийнх нь гадаад төрхөд татагдана гэж итгэдэг Сатаны зарц нар юм. Ичгүүргүй! Тэд бол хамгийн адгийн олиггүй амьтад!) Харин, энэ хугацаанд Миний хэлсэн эдгээр үгээр дамжуулан, ууган хөвгүүд биш хүмүүс үзэгдлийн талаар улам ойлгохоо больж, Миний үнэн биед итгэх итгэлээ алдсан. Дараа нь тэд эцэстээ унах хүртлээ аажмаар хайхрамжгүй болдог. Ийм хүмүүс өөрийн эрхгүй ингэдэг. Миний энэ үед хэлээд байгаа зүйлийн зорилго нь энэ юм; хүн бүр үүнийг харж (Би ууган хөвгүүдэд хэлж байна), мөн Миний айлдвар болон үйлдлээр дамжуулан Миний гайхалтай байдлыг харах хэрэгтэй. Намайг Энхийн Жонон, Мөнхийн Эцэг, Гайхамшигт, Зөвлөгч гэж яагаад хэлдэг вэ? Үүнийг Миний ялгамж чанар, Миний айлдвар эсвэл Миний хийдэг зүйлээс тайлбарлах нь хэтэрхий өнгөц хэрэг болно; үүнийг дурдахын ч хэрэггүй. Намайг Энхийн Жонон гэж дууддаг шалтгаан нь ууган хөвгүүдийг бүрэн төгс болгох Миний хүч, Сатаныг шүүх Миний шүүлт болон ууган хөвгүүдэд Миний олгосон эцэс төгсгөлгүй ерөөлөөс үүддэг. Өөрөөр хэлбэл, зөвхөн ууган хөвгүүд л Намайг Энхийн Жонон гэж дуудахад тэнцэнэ, учир нь Би ууган хөвгүүддээ хайртай бөгөөд “Энхийн Жонон” гэх зүйрлэл тэдний амнаас гарах ёстой. Тэдний хувьд, Би Энхийн Жонон билээ. Миний хөвгүүд болон ардууд Намайг Мөнхийн Эцэг гэдгээр минь мэднэ. Миний ууган хөвгүүд оршин байгаагийн улмаас, тэд Надтай хамт хааны эрх мэдлийг атгаж, бүх улс үндэстэн, ард түмнийг (өөрөөр хэлбэл хөвгүүд болон ардууд) захирдаг учраас хөвгүүд болон ардууд Намайг Мөнхийн эцэг гэж дуудах ёстой—ууган хөвгүүдийн дээр орших Бурхан Өөрөө гэсэн үг юм. Хөвгүүд, ардууд, ууган хөвгүүд биш хүмүүсийн хувьд, Би бол Гайхамшигт юм. Миний ажлын гайхалтай байдлаас болж үл итгэгчид Намайг огт харж чаддаггүй (учир нь Би тэдний нүдийг халхалсан), Миний ажлыг сайн харж чаддаггүй. Иймээс тэдэнд Би бол Гайхамшигт юм. Бүх диавол болон Сатаны хувьд Би бол Зөвлөгч, учир нь

Миний хийдэг бүхэн тэднийг шившиглэхийн тулд байдаг; Миний бүх үйлдэл Миний ууган хөвгүүдийн төлөө байдаг. Миний бүх алхам төвөггүй урагшилж, алхам бүртээ Би ялалтыг олж авдаг. Түүнчлэн, Би Сатаны бүх явуулгыг нэвт харж, тэдгээрийг Өөртөө үйлчлүүлэхэд ашиглаж, үүнийг сөрөг талаас Миний зорилгод үйлчлэх зүйл болгодог. Энэ нь Би “Зөвлөгч” байгаагийн утга учир бөгөөд үүнийг хэн ч өөрчилж, хэн ч бүрэн дүүрэн ойлгож чадахгүй. Харин Миний үнэн биеийн хувьд гэвэл, Би бол Энхийн Жонон, Мөнхийн Эцэг, мөн Зөвлөгч болоод Гайхамшигт юм. Үүнд худал зүйл ганц ч үгүй. Энэ бол няцаашгүй, хөдөлшгүй үнэн билээ!

Надад хэлэх зүйл маш их байна; үүнийг ердөө ч адилтгахын аргагүй. Иймд, та нар тэвчээртэй байж, хүлээ гэж Би шаардаж байна. Юу ч хийсэн бай, бүү гэнэт шийдээд яв. Учир нь та нарын өнгөрсөнд ойлгосон зүйл өнөөдөр хоцрогдож, хэрэглэгдэхээ больсон, одоо үе бол өөрчлөлтийн цаг үе—улс гүрнүүдийн хоорондох шилжилттэй адил. Энэ шалтгааны улмаас, та нар сэтгэлгээгээ өөрчилж, хуучин үзлээ хаях хэрэгтэй байна. Энэ бол “зөвт байдлын ариун дээл өмсөх”-ийн жинхэнэ учир утга юм. Зөвхөн Би л Өөрийнхөө үгийг тайлбарлаж чадна, зөвхөн Би л юу хийх үүрэг хүлээснээ мэднэ. Иймээс, зөвхөн Миний үг өө сэвгүй, бүхэлдээ Миний санаснаар байдаг бөгөөд тиймээс энэ бол зөвт байдлын ариун дээл өмсөж буй явдал юм. Хүний оюун санааны ойлголт бол ердөө төсөөлөл; хүний ойлголт нь өө сэвтэй, Миний санаа зорилгод хүрэх чадваргүй. Иймд, Би Өөрөө ярьж, Өөрөө тайлбарладаг бөгөөд “Би ажлаа Өөрөө хийдэг” гэж хэлэхдээ Би үүнийг хэлсэн билээ. Энэ нь Миний удирдлагын төлөвлөгөөний салшгүй хэсэг бөгөөд бүх хүн Намайг алдаршуулж, Намайг магтах ёстой. Миний үгийг ойлгож ухаарахын тухайд, Би тийм хүч чадлыг хүмүүст хэзээ ч өгөөгүй, тэдэнд үүнд зориулсан авьяас чадвар огтоос байхгүй. Энэ бол диаволыг шившиглэх Миний аргуудын нэг юм. (Хэрвээ хүмүүс Миний айлдварыг ойлгож, Миний санаа зорилгыг алхам тутамд судалж шинжиж чаддаг байсан бол Сатан хүмүүсийг хүссэн үедээ эзэмдэж чадах байсан бөгөөд үүний улмаас тэд Миний эсрэг болж, ууган хөвгүүдийг сонгох зорилгод минь хүрэх боломжгүй болгох байсан юм. Хэрвээ Би бүх нууцыг ойлгоод, хэний ч ойлгож чадахааргүй айлдварыг Миний үнэн бие айлдаж чаддаг байсан бол Сатан Намайг ч бас эзэмдэж чадах байсан. Махбодод байхдаа огтоос ер бусын биш байдгийн минь шалтгаан энэ юм.) Эдгээр үгийн ач холбогдлыг тодорхой ойлгож, Намайг дагах нь хүн бүрийн хувьд зайлшгүй чухал. Гүнзгий үг, сургаалуудыг өөрсдөө ойлгох гэж бүү оролд!

102-Р БҮЛЭГ

Би тодорхой хэмжээнд ярьж, Миний ажил тодорхой цэгт хүрээд байна; та нар дор бүрнээ Миний хүслийг ойлгож, янз бүрийн хэмжээгээр Миний ачаанд санаа тавих чадвартай байх хэрэгтэй. Одоо бол махан биеэс сүнсний ертөнц рүү шилжих

шийдвэрлэх мөч—та нар бол эрин үеүдийг туулж байгаа анхдагчид, орчлон ертөнц, газрын зах хязгаарыг хөндлөн гулд туулдаг орчлон ертөнцийн хүмүүс билээ. Та нар бол Миний хамгийн эрхэм; Миний хайрладаг хүмүүс. Миний шаргуу хүчин чармайлт бүгд та нарын төлөө байсан учраас та нараас өөр хүнийг Би хайрладаггүй гэж хэлж болно. Та нар үүнийг мэддэггүй байж болох уу? Би яагаад бүх зүйлийг бүтээх болов? Яагаад тэдгээрийг бүгдийг нь та нарт үйлчлүүлэхээр нааш цааш болгох болов? Энэ бүх үйлдэл нь та нарыг гэсэн Миний хайрын илэрхийлэл юм. Уулс, уулан дахь бүх зүйл, газар дэлхий, газар дэлхий дээрх бүх зүйл та нарыг олж авсны төлөө Намайг магтаж, алдаршуулдаг. Үнэхээр бүх зүйл хийгдсэн; түүгээр ч үл барам бүх зүйл нэгд нэгэнгүй хийгдсэн. Та нар надад цангинасан гэрчлэл хийж, Миний төлөө диаволууд болоод Сатаныг шившиглэсэн. Миний гадна байгаа бүх хүн, хэрэг явдал, юмс Миний эрх мэдэлд захирагдаж, Миний удирдлагын төлөвлөгөө дууссанаас үүдэн бүгд өөрсдийн төрлийг дагадаг (Миний ардууд Надад харьяалагдаж, Сатаны төрлийнхөн бүгд галт нуурт харьяалагддаг—тэд ёроолгүй нүхэнд унаж, тэндээ мөнхөд уйлж, үүрд мөхөх болно). Би “мөхөх” болон “тэр цагаас эхлэн тэдний сүнс, сэтгэл, биеийг авах” тухай ярихдаа тэднийг Сатанд хүлээлгэн өгч, дэвслүүлэхийг зөвшөөрч байгааг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Миний гэрийн биш бүх хүн сүйрэл хүртэж, оршин тогтнохоо болино. Энэ нь хүмүүсийн төсөөлдөг шиг нас барна гэсэн үг биш. Миний бодлоор бол, Миний гадна байгаа бүхэн оршин байдаггүй гэж хэлж болох бөгөөд энэ нь мөхлийн жинхэнэ утга учир юм. Хүний нүдэнд, эдгээр зүйл оршин байгаа мэт харагдсаар байх боловч, Миний бодлоор тэд хэдийнээ юу ч биш болсон агаад үүрд мөнх мөхөх болно. (Миний ажиллахаа больсон хүмүүс Миний гадна байдаг гэдгийг Би онцлон хэлж байна.) Хүмүүс яаж ч бодоод, үүнийг ойлгож чадахгүй, яаж ч сайн хараад, нэвтэрч чадахгүй. Би тэднийг гэгээрүүлж, гэрэлтүүлж, илэрхий хэлж өгөхгүй л бол хүмүүс тодорхой ойлгож чадахгүй. Түүнчлэн, тэд энэ талаар улам будилж, бүр ч илүү хоосон санагдаж, дагах зам алга гэдгийг улам бүр мэдэрнэ—тэд бараг л үхсэн хүн шиг байдаг. Яг одоо ихэнх хүн (ууган хөвгүүдээс бусад бүх хүн гэсэн үг) ийм нөхцөл байдалд байна. Би эдгээрийг маш тодорхой хэлсэн атал энэ хүмүүс ямар ч хариу үйлдэл хийхгүй, махан биеийн баяр цэнгэлдээ анхаарсаар байдаг. Тэд идээд дараа нь унтдаг; унтаад, дараа нь иддэг. Миний үгийг тунгаан боддоггүй. Тэд эрч хүчтэй байсан ч гэсэн энэ нь хэсэгхэн хугацаанд л байдаг; дараа нь тэд өнөөх янзаараа, Намайг огтоос сонсоогүй мэт ердөөс өөрчлөгдөөгүй байдаг. Эд бол ямар ч ачаагүй, байдаг л нэг хэрэггүй хүмүүс; тэд бол хамгийн илэрхий сорон мөлжигчид юм. Хожим Би тэднийг нэг нэгээр нь хаях болно; санаа бүү зов! Би тэднийг нэг нэгээр нь ёроолгүй нүх рүү буцаан илгээнэ. Ариун Сүнс ийм хүмүүс дээр хэзээ ч ажиллаагүй, тэдний хийдэг бүхэн хүлээн авсан авьяас билгээс нь урган гардаг. Би энэ авьяас билгийн талаар ярихдаа, энэ бол Миний үйлчлэл үзүүлэгч, ямар ч амьгүй хүмүүс гэсэн утгаар хэлдэг. Би тэдний хэнийг нь ч хүсдэггүй, бүгдийг нь таягдан хаяна (харин яг одоо тэд бага зэрэг хэрэгтэй хэвээр байна). Үйлчлэл

үзүүлэгчид та нар, сонс! Чамайг ашиглаж байгаа минь Би чамайг ивээдэг гэсэн үг гэж бүү бод; энэ нь тийм ч энгийн биш. Хэрвээ Надаар өөрийгөө ивээлгэхийг хүсэх аваас чи Миний сайшаадаг, биечлэн төгс болгодог хүн байх ёстой. Энэ бол Миний хайрладаг төрлийн хүн. Хүмүүс Намайг алдаа гаргасан гэж хэллээ ч, Би хэлсэн амнаасаа хэзээ ч буцахгүй. Та нар үүнийг мэдэх үү? Үйлчлэл үзүүлдэг хүмүүс бол үхэр, адуу; тэд яаж Миний ууган хөвгүүд байж чадах билээ? Тэгвэл утгагүй хэрэг болох бус уу? Байгалийн хуулийг зөрчиж буй хэрэг болох бус уу? Миний амь, Миний хэв чанар байдаг хэн боловч Миний ууган хөвгүүд билээ. Энэ бол үндэслэлтэй зүйл; хэн ч үүнийг няцааж чадахгүй. Ийм л байх ёстой; эс бөгөөс энэ үүргийг гүйцэтгэж чадах хэн ч байхгүй, орлож чадах хэн ч байхгүй. Энэ бол сэтгэл хөдлөлөөр үйлдсэн асуудал биш, учир нь Би бол зөвт Бурхан Өөрөө; Би бол ариун Бурхан Өөрөө. Би бол сүр жавхлант, халдашгүй Бурхан Өөрөө билээ!

Хүмүүст боломжгүй юм болгон, Миний хувьд төвөггүй, чөлөөтэй явагддаг. Хэн ч үүнийг зогсоож чадахгүй, хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Үлэмж том энэ дэлхий бүхэлдээ Миний гарт байхад өчүүхэн диавол Сатаныг дурдаад ч хэрэггүй. Хэрвээ Миний удирдлагын төлөвлөгөө байгаагүй бол, мөн Миний ууган хөвгүүд байгаагүй бол үхлийн үнэр нэвт шингэсэн энэ хуучин ёрын муу, замбараагүй эрин үеийг Би аль эрт устгачих байсан. Гэхдээ Би зохистой авирладаг, хөнгөн хуумгай ярьдаггүй. Намайг ямар нэг зүйл хэлмэгц л гүйцэлдэх болно; тийм биш байсан ч гэсэн, Миний мэргэн ухааны тал үргэлж байдаг, энэ нь Миний төлөө бүхнийг гүйцэлдүүлж, Миний үйлдлүүдэд зам нээж өгнө. Учир нь, Миний үг бол Миний мэргэн ухаан; Миний үг бол бүх зүйл. Хүмүүс тэдгээрийг үндсээр нь ойлгож чаддаггүй, учрыг нь олж чаддаггүй. Би байнга “галт нуур”-ыг дурддаг. Тэр нь юу гэсэн үг вэ? Хүхэртэй галт нуураас ямар ялгаатай вэ? Хүхэртэй галт нуур нь Сатаны нөлөөг хэлдэг бол галт нуур нь бүх дэлхий Сатаны эзэмшилд байхыг хэлдэг. Дэлхий дээр байгаа бүх хүн галт нууранд золиос болдог (өөрөөр хэлбэл, тэд улам бүр ялзарч, ялзрал нь тодорхой хэмжээнд хүрэхэд Би тэднийг нэг нэгээр нь устгана, Би ганц үг айлдаад л үүнийг амархан хийж чадна). Миний уур хилэн их байх тусам, галт нуур даяар дүрэлзэх галын дөл ч мөн адил өндөр байна. Энэ нь, хүмүүс улам бүр ёрын муу болсоор байгааг хэлдэг. Миний уур хилэн тэсрэх цаг нь бас галт нуур дэлбэрэх цаг байх болно; өөрөөр хэлбэл, энэ нь бүх орчлон ертөнц мөхөх цаг байх болно. Тэр өдөр, Миний хаанчлал дэлхий дээр бүрэн биеллээ олж, шинэ амьдрал эхэлнэ. Энэ бол удахгүй биелэх зүйл юм. Намайг үүнийг ярьж эхэлснээр бүх зүйл нүдний өмнө биелнэ. Энэ бол юмсын талаарх хүний үзэл бодол, харин Миний үзэл бодлоор бол, аливаа зүйл урьдаас гүйцэлдчихсэн, учир нь Миний хувьд бүх зүйл хялбархан. Би ярилаа, биеллээ; Би ярилаа, бүтээн байгуулагдлаа.

Та нар өдөр бүр Миний үгийг идэж, Миний сүмд үржил шимийг эдэлж, Миний амийн голоос ус ууж, Миний амийн модны жимс түүдэг. Тэгвэл Миний сүмийн үржил шим гэж юу вэ? Миний амийн голын ус гэж юу вэ? Амийн мод гэж юу вэ? Амийн модны жимс гэж юу юм бэ? Хэдийгээр эдгээр хэллэг нь түгээмэл ч гэсэн

бүгдээрээ будилсан бүх хүнд ухаарч ойлгохын аргагүй юм. Тэд эдгээр хэллэгийг хариуцлагагүй хэлж, болчимгүй, хаа хамаагүй хэрэглэдэг. Сүм дэх үржил шим гэдэг нь Миний хэлсэн үгийг ч тэр, Миний та нарт хайрласан нигүүлслийг ч хэлдэггүй. Тэгвэл, энэ нь үнэндээ юу гэсэн үг вэ? Эрт цаг үеэс хойш Миний сүм дэх үржил шимийг эдлэх хувь заяатай хүн хэзээ ч байгаагүй. Зөвхөн эцсийн өдрүүдэд л, Миний ууган хөвгүүдийн дундаас Миний сүм дэх энэхүү үржил шим гэж юу болохыг хүмүүс харж болно. Энэхүү хэллэгт “сүм” гэдэг нь Миний үнэн биеийг хэлдэг; Миний гэр орон Сион уулыг хэлж байгаа юм. Миний зөвшөөрөлгүйгээр хэн ч үүнд орж, эсвэл гарч чадахгүй. “Үржил шим” гэдэг нь юуг хэлдэг вэ? Энэ нь биед Надтай хамт хаанчилж чаддаг байх ерөөлийг хэлдэг. Ерөнхийдөө, энэ нь бие дотор Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчилж чаддаг байх ерөөлийг хэлдэг бөгөөд үүнийг ойлгоход хэцүү биш. Амийн голын ус хоёр утгатай: Нэг талаасаа энэ нь Миний дотоод оршихуйгаас урсан гарч буй амийн ус—өөрөөр хэлбэл Миний амнаас гарч буй үг бүрийг хэлдэг. Нөгөө талаас, энэ нь Миний үйлдлийн цаад мэргэн ухаан, стратегийг, мөн түүнчлэн Би юу болох, Надад юу байгааг хэлдэг. Миний үг дуусашгүй, далд нууц агуулдаг (нууцууд далд байхаа больсон гэж өнгөрсөнтэй харьцуулан дурдсан боловч ирээдүйд болох олон нийтийн илчлэлтэй харьцуулбал тэдгээр нь далд хэвээрээ л байгаа. “Далд байх” гэдэг нь туйлын биш; харьцангуй юм). Өөрөөр хэлбэл, амийн голын ус нь үүрд урссаар байдаг. Надад хязгааргүй мэргэн ухаан байдаг бөгөөд Би юу болох, Надад юу байгааг хүмүүс огтхон ч ухаарч чаддаггүй; өөрөөр хэлбэл, амийн голын ус үүрд урсдаг. Хүний үзэл бодлоор бол олон төрлийн бодит мод байдаг ч амийн модыг хэн ч, хэзээ ч олж хараагүй. Гэхдээ, өнөөдөр хүмүүс үүнийг хардаг ч гэсэн танихгүй л байдаг—гэсэн атлаа тэд бүр амийн модноос идэх тухай ярьдаг. Үнэхээр инээдтэй! Тэд үүнийг ялгахгүй идэх биз! Өнөөдөр хүмүүс үүнийг хардаг ч таньдаггүй гэж Би яагаад хэлдэг вэ? Би яагаад тэгж хэлдэг вэ? Та нар Миний үгийн утгыг ойлгож байна уу? Өнөөдрийн бодитой Бурхан Өөрөө бол Миний үнэн бие бөгөөд Тэрээр амийн мод юм. Хүний үзэл ашиглаж Намайг бүү хэмж. Гаднаасаа мод шиг харагддаггүй ч үнэндээ амийн мод гэдгийг минь чи мэдэх үү? Миний хөдөлгөөн бүр, Миний хэл яриа, зан авир бол амийн модны жимс, тэдгээр нь Миний үнэн бие юм—тэдгээр нь Миний ууган хөвгүүдийн идэх ёстой зүйл тул эцэст нь Миний ууган хөвгүүд болон Би яг ижилхэн болох болно. Тэд Намайг амьдран харуулж, гэрчлэх чадвартай болно. (Эдгээр нь биднийг сүнсний ертөнц рүү орсны дараа болох зүйл билээ. Зөвхөн биед л бид яг ижилхэн байж чадна; махбодод бид бараг ижилхэн байх ч, өөрийн гэсэн эрхэмлэдэг зүйлтэй байсаар л байна.)

Би Өөрийн ууган хөвгүүд дэх Өөрийн хүчийг харуулаад зогсохгүй, ууган хөвгүүдийнхээ бүх улс үндэстэн, ард түмнийг засаглаж байгаагаар нь Өөрийн хүчийг харуулах болно. Энэ бол Миний ажлын нэг алхам. Одоо бол хамгийн чухал үе, түүнчлэн, одоо бол шийдвэрлэх мөч юм. Бүх зүйл гүйцэлдэхэд та нар Миний гар юун дээр ажиллаж дуусаж байгаа, Би хэрхэн төлөвлөж, хэрхэн удирддагийг

харна—харин энэ нь тодорхойгүй зүйл биш. Дэлхийн улс орон бүрийн хөгжил хөдөлгөөнөөс харвал энэ нь тийм ч холгүй байна; энэ бол хүмүүсийн төсөөлж, түүнчлэн, урьдчилан харж чадахгүй зүйл юм. Ерөөгдөж, шагнуулах боломжийг алдахгүйн тулд та нар болгоомжгүй, хайхрамжгүй байж огт болохгүй. Хаанчлалын хэтийн ирээдүй энүүхэнд байна, дэлхий ертөнц бүхэлдээ аажмаар үхэж байна. Ёроолгүй нүх, хүхэртэй галт нуураас уйлах дуун тэсрэн гарч хүмүүсийг цочирдуулж, айлгаж, нүүрээ хийх газаргүй мэт санагдуулдаг. Миний нэрээр сонгогдож, дараа нь таягдан хаягдсан хэн боловч эцэст нь ёроолгүй нүхэнд унана. Тиймээс Миний олон удаа хэлсэнчлэн, Өөрийнхөө таягдан хаях хүмүүсийг Би ёроолгүй нүхэнд шиднэ. Бүх дэлхий ертөнцийг сүйрүүлэхэд, устгагдсан бүхэн хүхэртэй галт нууранд унана. Өөрөөр хэлбэл, эдгээр нь галт нуураас хүхэртэй галт нуур луу шилжих болно. Тэр үед, хүн бүрийн хувьд мөнхийн сүйрэл (Миний гадна байгаа бүх хүн гэсэн үг), эсвэл мөнхийн амийн (Миний дотор байгаа бүх хүн гэсэн үг) аль нь болохыг тогтоох болно. Тэр үед, Би болон Миний ууган хөвгүүд хаанчлалаас гарч, мөнх байдал руу орно. Энэ бол хожим биелэх зүйл; Би та нарт одоо хэлсэн ч гэсэн та нар ойлгохгүй. Та нар зөвхөн Намайг дагаж, Миний гэрэлд алхаж, Миний хайранд Надад бараа болж, Миний гэрт Надтай хамт баяр цэнгэлийг амсаж, Миний хаанчлалд Надтай хамт хаанчилж, Миний эрх мэдэлд байх бүх улс үндэстэн, ард түмнийг Надтай хамт захирч чадна. Миний дээр дүрсэлсэн бүхэн та нарт Миний өгч буй эцэс төгсгөлгүй ерөөлүүдийг бүрдүүлдэг билээ.

103-Р БҮЛЭГ

Аянга мэт нижигнэсэн дуу хоолой гарч, бүхий л орчлонг донсолгодог. Энэ нь хүмүүс амжин булталж чадахааргүй дүлийрүүлэм байдаг. Зарим нь алагдаж, зарим нь устгагдаж, мөн зарим нь шүүгддэг. Энэ бол үнэхээр хэн ч, хэдийд ч хараагүй үзэгдэл юм. Сайн сонс: аянгын нижигнээнийг уйлах дуу дагалдах бөгөөд энэ дуу нь Үхэгсдийн орноос гардаг; тамаас гардаг. Энэ нь Надаар шүүгдсэн тэрслүү хөвгүүдийн гашуун дуу билээ. Миний хэлдгийг сонсоогүй, Миний үгийг хэрэгжүүлээгүй хүмүүс хатуу шүүгдэж, Миний уур хилэнгийн хараалыг хүртсэн. Миний дуу хоолой бол шүүлт ба уур хилэн; Би хэнд ч зөөлөн хандаж, хэнд ч өршөөл үзүүлэхгүй, учир нь Би бол зөвт Бурхан Өөрөө, Би уур хилэн эзэмшдэг, Би бол шатаалт, Би бол цэвэрлэгээ, мөн сүйрлийг эзэмшдэг. Надад нуусан, эсвэл сэтгэл хөдлөх зүйл огт үгүй, харин бүх зүйл ил, зөвт агаад алагчлалгүй юм. Миний ууган хөвгүүд бүх улс үндэстэн, ард түмнийг захиран сэнтий дээр хэдийнээ Надтай хамт байгаа учраас шударга биш, зөвт бус зүйлс болон хүмүүс одоо шүүгдэж эхлээд байна. Би юуг ч орхилгүй, тэднийг гүйцэд илчлэн, нэг нэгээр нь байцаана. Учир нь, Миний шүүлт бүрэн илчлэгдэж, бүрэн нээлттэй болсон ба Би огт юу ч үлдээгээгүй; Миний хүсэлд нийцэхгүй бүх зүйлийг Би хаяж, ёроолгүй нүхэнд үүрдийн үүрд мөхөөнө. Тэндээ

мөнхөд шатаг. Энэ бол Миний зөвт байдал, энэ бол Миний шударга байдал. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй бөгөөд бүгд Миний тушаал дор байх ёстой.

Ихэнх хүн үг бол ердөө л үг, баримт бол баримт гэж бодон Миний айлдварыг үл ойшоодог. Тэд сохор юм! Би бол итгэмжит Бурхан Өөрөө гэдгийг тэд мэддэггүй гэж үү? Миний үг, баримтууд нэгэн зэрэг тохиолддог. Энэ үнэхээр тийм биш гэж үү? Хүмүүс Миний үгийг ердөө л ухаардаггүй, харин зөвхөн гэгээрсэн хүмүүс л үнэхээр ойлгож чадна. Энэ бол баримт. Хүмүүс Миний шүүлт буух үед байтугай, Миний үгийг хармагцаа ухаан алдталаа айж, нуугдах гэж ийш тийш яаран гүйлддэг. Би бүх зүйлийг бүтээж, дэлхийг устгаж, ууган хөвгүүдийг бүрэн төгс болгох үед энэ бүхэн Миний амнаас гарсан ганц үгээр гүйцэлдсэн. Яагаад гэвэл, Миний үг өөрөө эрх мэдэл, шүүлт юм. Хүн Би бол шүүлт, сүр жавхлан гэж хэлж болно; энэ бол өөрчилж болшгүй баримт юм. Энэ нь Миний захиргааны зарлигийн нэг тал; хүмүүсийг шүүдэг Миний нэг арга зам юм. Миний нүдэнд бол юм бүхэн—бүх хүн, бүх хэрэг явдал, бүх зүйлийг оролцуулаад—Миний гарт, Миний шүүлт дор байдаг. Хэн ч, юу ч дурааараа, цадиггүй аашилж зүрхэлдэггүй бөгөөд бүгд Миний амнаас гарах үгийн дагуу гүйцэлдэх ёстой. Хүний үзлээр бол, хүн Миний үгэнд, хүн бүхэн итгэдэг. Миний Сүнс дуу хоолой гаргахад, хүмүүс эргэлздэг. Миний бүхнийг чадагч байдлын талаар хүмүүст өчүүхэн ч мэдлэг байдаггүй бөгөөд Миний эсрэг гүтгэлэг хүртэл хийдэг. Миний үгэнд эргэлздэг хэн ч бай, Миний үгийг басамжилдаг хэн ч бай, тэд бол устгагдах хүмүүс; тэд бол үүрдийн мөхлийн хүүхдүүд юм гэдгийг Би одоо чамд хэлье! Ууган хөвгүүд маш цөөхөн байдаг гэдгийг үүнээс харж болно, учир нь Би ингэж ажилладаг билээ. Би урьд хэлсэнчлэн хуруугаа ч хөдөлгөлгүй бүх зүйлийг гүйцэлдүүлдэг; Би гагцхүү Өөрийнхөө үгийг л ашигладаг. Тэгэхээр энд Миний бүхнийг чадагч байдал оршдог. Миний үгээс Миний хэлэх зүйлийн эх сурвалж, зорилгыг хэн ч олж чадахгүй. Хүмүүс үүнд хүрч чадахгүй бөгөөд зөвхөн Миний удирдлагыг дагахдаа бүхнийг Миний зөвт байдлын дагуу, Миний хүсэлд нийцүүлэн үйлдэн хийж чадсанаар Миний гэр бүлийг зөвт байдалтай, амар тайван байж, үүрд бат, гуйвалтгүй мөнх амьдардаг болгоно.

Миний шүүлт хүн болгонд очиж, Миний захиргааны зарлиг хүн бүрд хүрч, Миний үг ба Миний үнэн бие хүн бүрд илчлэгддэг. Энэ бол Миний Сүнсний агуу ажлын цаг (энэ үед ерөөгдөх хүмүүс, гай зовлон амсах хүмүүсийг ялган салгана). Миний үг гармагц, Би ерөөгдөх хүмүүс болон гай зовлон амсах хүмүүсийг ялгаж салгачихсан байна. Энэ бүгд тов тодорхой, Би үүнийг бүгдийг нь ганц хяламхийхэд л харж чадна. (Үүнийг Би хүн чанартайгаа холбогдуулан хэлж байна; иймд эдгээр үг нь Миний урьдчилан тогтоож, сонгосонтой зөрчилддөггүй.) Би уул толгод, гол горхи ба бүх зүйлийн дунд, орчлонгийн орон зайгаар газар бүрийг ажиглан, цэвэрлэн хэсүүчилдэг бөгөөд ингэснээр тэдгээр бохир, садар самуун газар нутаг бүгд оршин тогтнохоо больж, Миний үгийн үр дүнд юу ч биш болон чандарлагдана. Надад бүх зүйл хялбархан. Хэрвээ одоо үе нь дэлхийг устгана гэж Миний урьдчилан тогтоосон цаг байсан бол Би үүнийг ганц үгээр л залгих байсан. Гэхдээ одоо үе бол тэр цаг

биш. Миний төлөвлөгөөг үймүүлж, Миний удирдлагад саад болохгүйн тулд Намайг энэ ажлыг хийхээс өмнө бүгд бэлэн байх ёстой. Үүнийг хэрхэн ухаалгаар хийхээ Би мэднэ: Надад Миний мэргэн ухаан бий, Надад Миний өөрийн зохицуулалт бий. Хүмүүс хуруугаа ч хөдөлгөх ёсгүй; Миний гарт үхэхээс болгоомжил. Миний захиргааны зарлигт энэ аль хэдийн хүрсэн. Үүнээс хүн, Миний захиргааны зарлигийн хатуу чангыг, мөн тэдгээрийн цаадах хоёр тал бүхий зарчмуудыг харж чаддаг: Нэг талаас, Миний хүсэлтэй нийцдэггүй, Миний захиргааны зарлигийг зөрчдөг бүх хүнийг Би алдаг; нөгөө талаас, Миний захиргааны зарлигийг зөрчдөг бүхнийг Би хилэгнэхдээ хараадаг. Энэ хоёр тал салшгүй бөгөөд Миний захиргааны зарлигийн цаадах гүйцэтгэх зарчмууд юм. Хүн хэчнээн үнэнч байх нь хамаагүй, хүн бүртэй энэ хоёр зарчмын дагуу, ямар ч сэтгэлийн хөдлөлгүйгээр харьцдаг. Газар дэлхийн бүх зүйлийг, ертөнцийн бүх юмыг, мөн Миний хүсэлтэй нийцдэггүй бүх зүйлийг шатаах Миний зөвт байдал, Миний сүр жавхлан, Миний уур хилэнг харуулахад энэ нь хангалттай. Миний үгэнд далдалсан нууц байдаг бөгөөд Миний үгэнд бас илчлэгдсэн нууц байдаг. Иймээс хүний үзлээр бол, Миний үг хүний оюун санаанд хэзээд ойлгогдошгүй, мөн Миний зүрх сэтгэл үргэлж тайлагдашгүй байдаг. Тэгэхээр, Би хүмүүсийг үзэл болон бодол санаанаас нь салгах ёстой. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний хамгийн чухал зүйл. Өөрийн ууган хөвгүүдийг олж авч, хийхийг хүссэн зүйлээ хэрэгжүүлэхийн тулд Би үүнийг ийм маягаар хийх ёстой.

Дэлхийн гай гамшиг өдрөөс өдөрт үлэмж болж, Миний гэрт аюулт гамшгууд улам хүчтэй болж байна. Хүмүүст нуугдах газар, биеэ далдлах газар үнэхээр хаана ч байхгүй. Шилжилт яг одоо явагдаж байгаа учир дараачийн алхмаа хаана өнгөрөөхийг хүмүүс мэддэггүй. Энэ нь Миний шүүлтийн дараа л тодорхой болно. Санаж яв! Эдгээр нь Миний ажлын алхам бөгөөд Миний ажилладаг арга юм. Би Өөрийн ууган хөвгүүдийг бүгдийг нэг нэгээр нь тайвшруулж, алхам алхмаар өргөнө; үйлчлэл үзүүлэгчийн хувьд гэвэл, Би тэднийг бүгдийг нэг нэгээр нь таягдан хаяж, орхино. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Бүх үйлчлэл үзүүлэгч илчлэгдсэний дараа Миний ууган хөвгүүд ч мөн илчлэгдэнэ. (Миний хувьд, энэ нь хэтэрхий хялбар. Миний үгийг сонссоны дараа тэр бүх үйлчлэл үзүүлэгч Миний үгийн шүүлт ба заналхийлэл дор ухрах бөгөөд зөвхөн Миний ууган хөвгүүд үлдэнэ. Энэ бол сайн дурын зүйл ч биш, хүний хүслээр өөрчилж чадах зүйл ч биш; харин энэ бол Миний Сүнс биечлэн ажиллаж байгаа хэрэг.) Энэ бол алс хэтийн үйл явдал биш бөгөөд та нар Миний ажил болон Миний үгийн энэ үе шатнаас үүнийг зарим нэг хэмжээгээр ойлгож чаддаг байх хэрэгтэй. Би яагаад ийм ихийг хэлдэг, мөн Миний айлдварууд ийм таагдашгүй чанартай байдаг нь хүмүүст ойлгомжгүй юм. Би Өөрийн ууган хөвгүүдтэй тайтгарал, өршөөл болон хайрын өнгөөр ярьдаг (яагаад гэвэл, Би энэ хүмүүсийг үргэлж гэгээрүүлдэг бөгөөд Би тэднийг орхихгүй, учир нь Би тэднийг урьдчилан тогтоосон билээ), харин Би ууган хөвгүүдээсээ бусад хүмүүстэй ширүүн шүүлт, заналхийлэл, сүрдүүлэг хэрэглэн харьцаж, мэдрэлийн төв нь байнга ажилладаг болтол нь тэднийг үргэлж айлгадаг. Нөхцөл байдал

тодорхой хэмжээнд солигдоход тэд энэ байдлаасаа зугтана (Намайг дэлхийг сөнөөхөд энэ хүмүүс ёроолгүй нүхэнд байх болно), гэвч тэд хэзээ ч Миний шүүлтийн гараас зугтах юм уу, энэ нөхцөл байдлаас зайлахгүй. Тэгэхээр энэ бол тэдний шүүлт; энэ бол тэдний гэсгээлт. Гаднынхан ирэх өдөр Би энэ хүмүүсийг нэг нэгээр нь илчилнэ. Энэ бол Миний ажлын нэг алхмууд. Өмнө нь Би эдгээр үгийг хэлсний цаад санаа зорилгыг та нар одоо ойлгож байна уу? Миний бодлоор бол биелээгүй аливаа зүйл бол бас биелсэн зүйл, гэвч биелсэн зүйл нь заавал гүйцэлдсэн зүйл байх албагүй. Учир нь Надад Миний мэргэн ухаан, Өөрийн ажиллах арга байдаг ба эдгээр нь хүмүүсийн хувьд ердөө л ухаарахын аргагүй байдаг. Энэ алхмаар үр дүнд хүрчихээд (Намайг эсэргүүцдэг бүх муу хүнийг илчилчхээд) Би дараагийн алхмаа эхлүүлнэ, учир нь Миний хүсэл саад тотгоргүй бөгөөд хэн ч Миний удирдлагын төлөвлөгөөг саатуулж, саад тотгор хийж зүрхэлдэггүй—тэд бүгд замаас зайлах ёстой! Агуу улаан лууны хүүхдүүд ээ, Намайг сонс! Би Өөрийн ууган хөвгүүдийг олж авч, та нарын эцгийг шившиглэж (энэ үгс агуу улаан лууны үр удамд чиглэсэн), Өөрийн ууган хөвгүүдийг дэмжиж, ууган хөвгүүдэд минь хийсэн хилс хэргийг засаж залруулахаар Сионоос ирж, энэ дэлхийд махбод болсон. Иймд дахин бүү зэрлэг авирла; Би ууган хөвгүүдээрээ та нарын учрыг олуулна. Урьд нь Миний хөвгүүд дээрэлхүүлж, дарлагдсан, харин Эцэг нь хөвгүүдийнхээ төлөө эрх мэдэл эзэмшсэнээс хойш Миний хөвгүүд хайрлан тэврэх тэвэрт минь эргэн ирж, дахин дээрэлхүүлж, дарлагдахгүй. Би бол зөвт бус биш; энэ нь Миний зөвт байдлыг харуулдаг бөгөөд энэ нь үнэхээр “Би хайрладаг хүнээ хайрлаж, үзэн яддаг хүнээ үзэн ядаж” байгаа хэрэг юм. Хэрвээ та нар Намайг зөвт бус гэж хэлдэг бол яаравчлан зайлах хэрэгтэй. Миний гэрт бүү ичгүүргүй авирла, бусдыг бүү завш. Чи гэр лүүгээ хурдан буцах ёстой, ингэснээр Би чамайг дахин харах хэрэггүй болно. Ёроолгүй нүх бол та нарын хүрэх газар бөгөөд та нарын амрах газар. Хэрвээ та нар Миний гэрт байгаа бол та нарт байх газар байхгүй, учир нь та нар бол ачлагын амьтад; Миний ашигладаг багаж юм. Та нар Надад цаашид хэрэггүй болохоор Би та нарыг чандарлахаар галд хаяна. Энэ бол Миний захиргааны зарлиг; Би үүнийг ингэж хийх ёстой; зөвхөн энэ л Миний ажилладаг арга замыг үзүүлдэг бөгөөд Миний зөвт байдал, Миний сүр жавхланг илчилдэг. Үүнээс ч чухал нь, зөвхөн энэ замаар Миний ууган хөвгүүд Надтай хамт эрх мэдэлтэйгээр хаанчилж чадна.

104-Р БҮЛЭГ

Миний гадна байгаа бүх хүн, үйл явдал, юмс оргүй хоосон руу алга болж, харин Миний дотор байгаа бүх хүн, үйл явдал, юмс Надаас бүхнийг олж авч, Надтай хамт алдар руу орж, Миний Сион уул, Миний өргөөнд орж, үүрд Надтай зэрэгцэн орших болно. Эхэнд Би бүх зүйлийг бүтээсэн, эцэст нь Өөрийн ажлыг гүйцээж, үүрд Хаан

болж захирах болно. Завсрын үед нь Би бас бүх ертөнцийг хөтөлж, удирдах болно. Хэн ч Миний эрх мэдлийг булааж авч чадахгүй, учир нь Би бол цор ганц Бурхан Өөрөө билээ. Түүнчлэн, Өөрийн эрх мэдлийг ууган хөвгүүддээ дамжуулах хүч Надад бий, ингэснээр тэд Надтай хамт хаанчилж чадна. Эдгээр нь мөнхөд оршиж, хэзээ ч өөрчлөх боломжгүй. Энэ бол Миний захиргааны зарлиг. (Би захиргааны зарлигаа хэлэлцэх бүртээ Миний хаанчлал дотор юу болдог, юу үүрд мөнх оршин тогтнож, хэзээ ч өөрчлөгдөх боломжгүй болохыг ярьж байдаг.) Хүн бүр чин сэтгэлээсээ үнэмшиж, Миний хайрладаг хүмүүсээс Миний агуу хүчийг харах ёстой. Хэн ч Миний нэрийг шившиглэж болохгүй—шившиглэсэн хэн боловч эндээс зайлах ёстой! Би өршөөлгүйдээ биш, харин чи зөв шударга биш байна. Хэрвээ чи Миний гэсгээлтийг зөрчвөөс, Би чамтай харьцаж, чамайг үүрд мөнх мөхөөх болно. (Мэдээжийн хэрэг, энэ бүгд нь Миний ууган хөвгүүд биш хүмүүст чиглэдэг.) Миний гэр энэ мэт хог новшийг хүлээж авахгүй, тиймээс хурдан эндээс зайл! Нэг минут, бүр нэг хором ч бүү саат! Чи Миний хэлснийг хийх ёстой, үгүй бол Би чамайг ганцхан үгээр устгах болно. Чи эргэлзсэн хэвээр биш, хууран мэхлэх гэж оролдсон хэвээр биш байсан чинь дээр шүү. Миний өмнө байхдаа утгагүй юм зохиодог, Миний нүүрэн дээр худал хэлдэг чи хурдан яв! Ийм зүйлд үрэх цаг Надад хязгаарлагдмал байна. (Үйлчлэл хийх цаг нь болоход энэ хүмүүс үйлчлэл хийж, явах цаг нь болоход тэд явах болно. Би аливааг өчүүхэн ч гэлгүй, минут, хором ч алдалгүй мэргэн ухаанаар хийдэг. Миний бүх үйлдэл зөвт, бүхэлдээ алдаа мадаггүй.) Харин ууган хөвгүүддээ Би хэмжээлшгүй хүлцэнгүй, та нарыг гэх хайр минь үүрд мөнх болохоор Надтай хамт сайн ерөөл, мөнх амийг үүрд эдлэх боломжийг та нарт олгохын зэрэгцээ ямар ч бүтэлгүйтэл, шүүлтийг хэзээ ч туулах ёсгүй. (Энэ нь ерөөл эдэлж эхлэх үеийг чинь хэлдэг.) Энэ бол дэлхийг бүтээх үедээ Өөрийн ууган хөвгүүдэд өгсөн хэмжээлшгүй ерөөл болон амлалт билээ. Та нар эндээс Миний зөвт байдлыг харах хэрэгтэй: Би урьдчилан тогтоосон хүмүүсээ хайрладаг бөгөөд орхиж, таягдан хаясан хүмүүсээ үүрд мөнхөд үзэн яддаг.

Миний ууган хөвгүүдийн хувьд, та нар үргэлж өөрсдийн үүргийг чанд сахин, байрандаа баттай зогсож, Миний өмнө өргөгдсөн анхны боловсорсон жимс болж, Миний хувийн шалгалтыг хүлээн авах ёстой, ингэснээр та нар Миний алдар суутай дүр төрхийг амьдран харуулж, Миний алдрын гэрэл та нарын нүүрэнд гялалзаж, Миний айлдварууд та нарын амаар дамжин түгж, Миний хаанчлалыг та нар жолоодож, Миний хүмүүсийг та нар захирч чадна. Энд Би “анхны боловсорсон жимснүүд” мөн “өргөгдөх” гэх мэт нэр томьёог дурдлаа. Анхны боловсорсон жимснүүд гэж юу вэ? Хүмүүсийн үзлээр бол энэ нь эхний өргөгдсөн хэсэг хүн эсвэл ялагчид, ууган хөвгүүд гэж боддог. Эдгээр нь бүгд төөрөгдөл бөгөөд Миний үгийн алдаатай тайлбар юм. Анхны боловсорсон жимснүүд бол Надаас илчлэл хүлээж авсан, Би эрх мэдэл олгосон хүмүүс юм. “Анх боловсрох” гэдэг үг нь Миний эзэмшилд байхыг, Би урьдчилан тогтоож, сонгосныг хэлнэ. “Анх боловсрох” нь дэс дарааллаараа эхнийх гэсэн утгатай биш. “Анхны боловсорсон жимснүүд” нь хүний

нүдэнд харагддаг материаллаг зүйл биш юм. “Жимс” гэдэг нь анхилуун үнэр ялгаруулдаг зүйлийг (энэ бол бэлгэдлийн утга) хэлдэг; өөрөөр хэлбэл Намайг амьдран харуулж, Миний илрэл болж, Надтай үүрд цуг амьдарч чаддаг хүмүүсийг хэлнэ. Би “жимснүүд”-ийн талаар ярихдаа Өөрийн хөвгүүд болон ардуудыг хэлж байгаа бол анхны боловсорсон жимснүүд гэдэг нь Надтай хамт хаанчлах ууган хөвгүүдийг хэлж байгаа юм. Иймд, “анхны боловсорсон” гэдгийг эрх мэдэл агуулдаг гэж тайлбарлах хэрэгтэй. Энэ бол үүний жинхэнэ утга юм. “Өргөгдөх” гэдэг нь хүмүүсийн төсөөлдөг шиг нам газраас өндөр газарт хүргэгдэнэ гэсэн үг биш; тэр нь ихээхэн буруу ойлголт юм. “Өргөгдөх” гэдэг нь Би урьдчилан тогтоож, дараа нь сонгохыг хэлдэг. Энэ нь Миний урьдаас тогтоож, сонгосон бүх хүнд чиглэдэг. Өргөгдсөн бүх хүн бол ууган хөвгүүдийн юм уу хөвгүүдийн байр суурийг олж авсан хүмүүс, эсвэл Бурханы ардууд юм. Энэ нь хүмүүсийн үзэлтэй хамгийн их нийцдэггүй. Ирээдүйд Миний гэрт хувь хүртэх хүмүүс бол Миний өмнө өргөгдсөн бүх хүн юм. Энэ нь туйлын үнэн, хэзээ ч өөрчлөгдөхгүй бөгөөд няцаахын аргагүй. Энэ бол Сатаны эсрэг хариу цохилт. Миний урьдчилан тогтоосон хэн боловч Миний өмнө өргөгдөнө.

“Ариун бүрээг” хэрхэн тайлбарладаг вэ? Та нар үүнийг юу гэж ойлгож байна? Яагаад үүнийг ариун бөгөөд аль хэдийн дуугарсан гэдэг вэ? Үүнийг Миний ажлын алхмуудаас тайлбарлаж, Миний ажлын арга барилаас ойлгох хэрэгтэй. Миний шүүлт олон нийтэд зарлагддаг үе бол Миний зан чанар бүх улс үндэстэн болон хүмүүст илчлэгддэг үе юм. Энэ үед ариун бүрээ дуугарсан билээ. Өөрөөр хэлбэл, Миний зан чанар ариун бөгөөд халдашгүй гэж Би үргэлж хэлдэг, иймээс ч “ариун” нь “бүрээ”-г дүрслэхэд хэрэглэгддэг. “Бүрээ” гэдэг нь Миний зан чанарыг хэлж байгааг, мөн Би юу болох, Надад юу байгааг төлөөлдөг гэдгийг үүнээс харж болно. Миний шүүлт өдөр бүр урагшилж, Миний хилэн өдөр бүр дүрэлзэж, Миний хараал Миний зан чанартай нийцдэггүй юм бүхэн дээр өдөр бүр тусдаг гэж бас хэлж болно. Тэгэхээр, Миний шүүлт эхлэх үе бол ариун бүрээ дуугардаг үе бөгөөд нэг агшин ч гацалгүйгээр, нэг минут, секунд ч зогсолгүйгээр өдөр бүр дуугарсаар байгаа. Одооноос эхлээд, агуу гамшиг аажмаар буухын хамтаар ариун бүрээ улам бүр чанга дуугарах болно. Өөрөөр хэлбэл, Миний зөвт шүүлтийн илчлэлтэй хамт Миний зан чанар улам бүр олон нийтэд ил болж, Би юу болох, Надад юу байгаа нь Миний ууган хөвгүүдэд улам бүр нэмэгдэх болно. Ирээдүйд Би ингэж ажиллана: Нэг талаас Өөрийн хайрладаг хүмүүсийг тэтгэж, аврах бол нөгөө талаас Өөрийн үгийг ашиглан үзэн яддаг хүмүүсээ илчилнэ. Санагтун! Энэ бол Миний ажлын арга барил, Миний ажлын алхмууд бөгөөд туйлын үнэн. Үүнийг Би бүтээснээс хойш төлөвлөж ирсэн бөгөөд хэн ч өөрчилж чадахгүй.

Миний үгийн олон хэсгийг хүмүүс ойлгоход хэцүү байсаар байгаа, иймээс Би Өөрийн ярианы хэв маяг болон нууцуудыг илчлэх Өөрийн арга барилыг улам сайжруулсан. Өөрөөр хэлбэл, Миний ярианы хэв маяг өдөр бүр өөр дүрс, арга барилаар өөрчлөгдөн, сайжирч байна. Эдгээр нь Миний ажлын алхмууд бөгөөд

тэдгээрийг хэн ч өөрчилж чадахгүй. Хүмүүс зөвхөн Миний хэлсэнтэй л нийцүүлэн ярьж, үйлдэж болно. Энэ бол туйлын үнэн. Би Өөрийн үнэн бие болон Өөрийн махбодод таарсан зохицуулалтыг хийсэн. Миний хүн чанарын үйлдэл, үйл хэрэг болгонд Миний бурханлаг чанарын мэргэн ухааны тал бий. (Хүн төрөлхтөн огтхон ч мэргэн ухаангүй тул ууган хөвгүүдэд Миний мэргэн ухаан бий гэдэг нь тэдэнд Миний бурханлаг зан чанар байгааг хэлж байгаа юм.) Ууган хөвгүүд тэнэг зүйл хийдэг нь, та нарт хүний шинж байсаар байгаа учраас тэр юм. Иймд, та нар хүний тийм тэнэглэлээс ангижирч, Миний хайрладаг зүйлийг хийж, Миний үзэн яддаг зүйлийг голох ёстой. Надаас гарсан хэн ч Миний дотор буцаж ирэх ёстой. Надаас төрсөн хэн ч Миний алдар дотор эргэн ирэх ёстой. Миний үзэн яддаг хүмүүсийг хаяж, Надаас нэг нэгээр нь таслах ёстой. Эдгээр нь Миний ажлын алхмууд юм; энэ нь Миний удирдлага бөгөөд Миний 6,000 жилийн бүтээлийн төлөвлөгөө билээ. Миний хаясан хүмүүс бүгд захирагдаж, Надаас дуулгавартайгаар явах хэрэгтэй. Би тэдэнд ерөөл хайрласан учир Миний хайрладаг хүмүүс бүгд Намайг магтах болно, тэгж байж Миний нэр улам алдартай болж, Миний алдар суутай царайнд алдрын гэрэл нэмэгдэж чадах ба тэгснээр тэд Миний алдарт Миний мэргэн ухаанаар дүүрэн байж, Миний алдрын гэрэлд Миний нэрийг улам илүү алдаршуулж чадна!

105-Р БҮЛЭГ

Миний үгийн цаад зарчим, Миний ажиллаж байгаа байдлаас болж хүмүүс Намайг үгүйсгэдэг; энэ бол маш удаан хугацаанд ярьж байгаагийн минь цаад зорилго юм (энэ нь агуу улаан лууны бүх үр садад чиглэдэг). Энэ бол Миний ажлын ухаалаг арга барил; агуу улаан лууг шүүх Миний шүүлт. Энэ бол Миний стратеги, нэг ч хүн үүнийг бүрэн дүүрэн ойлгож чадахгүй. Эргэх мөч бүрд—өөрөөр хэлбэл, Миний удирдлагын төлөвлөгөөний шилжилтийн үе шат бүрд—зарим хүнийг таягдан хаях ёстой байдаг; тэд Миний ажлын дарааллын дагуу таягдан хаягддаг. Энэ, зөвхөн энэ л Миний удирдлагын төлөвлөгөө бүхэлдээ ажиллах арга зам юм. Би таягдан хаяхыг хүссэн хүмүүсээ нэг нэгээр нь гаргаж хаясныхаа дараа Өөрийн ажлын дараагийн алхмыг эхэлдэг. Гэхдээ энэ нь эцсийн удаа таягдан хаяж буй хэрэг (энэ нь Хятад дахь чуулганууд дотор гэсэн үг юм) бөгөөд энэ нь бас дэлхийг бүтээснээс хойш хамгийн олон тооны хүнийг шилжилтийн үе шатанд таягдан хаясан байх үе юм. Түүхийн туршид хүмүүсийг таягдан хаях бүрд хожмын ажилд үйлчлэл үзүүлэхээр нэг хэсгийг нь үлдээж байсан. Гэвч энэ удаад өмнөхтэй адилгүй; цэвэрхэн агаад үр дүнтэй байна. Энэ бол цаг үеэс хамгийн чухал агаад хамгийн иж бүрэн нь юм. Хэдийгээр, ихэнх хүн Миний үгийг уншсаныхаа дараа ихэнх хүн оюун санаанаасаа эргэлзээг хүчээр авч хаях гэж оролддог боловч эцэст нь үүнийг ялан дийлж чаддаггүй бөгөөд эцэстээ өөрсдийнхөө тэмцэлд ялагддаг. Энэ бол тэдний шийдэж чадах зүйл биш, учир нь Миний урьдчилан тогтоосон

хүмүүс зугтаж чадахгүй, Өөрийн урьдчилан тогтоогоогүй хүмүүсийг Би зөвхөн зэвүүцдэг. Миний таалж хардаг хүмүүс л Миний хайрладаг хүмүүс; эс бөгөөс ганц ч хүн Миний хаанчлалд чөлөөтэйгөөр орж, гарч болохгүй. Энэ Миний төмөр саваа, энэ нь л Миний захиргааны зарлигийг хэрэгжүүлж буйн хүчирхэг гэрчлэл, бүрэн билээ. Энэ нь золбоолог байх төдий хэрэг биш гэдэг нь гарцаагүй. Би яагаад Сатан уналтын өмнө хүчин мөхөс байсан гэж хэлсэн бэ? Эхэндээ тэр хүчтэй байсан ч, Миний гарт байдаг; хэрвээ Би түүнийг хэвт гэвэл тэр хэвтэх ёстой, хэрвээ Би түүнийг өндийн босож Надад үйлчлэл үзүүл гэвэл өндийн босож, Надад сайн үйлчлэл үзүүлэх ёстой. Сатан үүнийг хийхийг хүсэж байгаа юм биш; харин Миний төмөр саваа Сатаныг захирдаг бөгөөд зөвхөн ингэж байж л тэр зүрх сэтгэлдээ болон үгээрээ үнэмшдэг. Миний захиргааны зарлиг түүнийг захирдаг, Надад Миний сүр хүч байгаа, тиймээс Сатан бүрэн үнэмшихээс өөр аргагүй; тэр эсэргүүцлийн ул мөргүйгээр Миний хөлийн тавиур дор дэвслэгдэх ёстой. Өнгөрсөнд, Миний хөвгүүдэд үйлчлэл үзүүлж байхдаа, Сатан туйлын увайгүй байж, тэднийг дур зоргоороо дээрэлхэж, тэгснээрээ Намайг шившиглэнэ хэмээн найдаж, Намайг чадваргүй гэж хэлж байсан. Ямар сохор юм бэ! Би чамайг үхтэл чинь дэвслэх болно! Чи ахин нэгэнтээ харгис байгаад үзээрэй! Миний хөвгүүдэд дахин хүйтэн хайхрамжгүй хандаад үзээрэй! Хүмүүс шударга байх тусам, Миний үгийг сонсож, Надад захирагддаг байх тусам чи тэднийг төдий чинээ дээрэлхэж, тусгаарладаг (энд Би хамсаатнуудаа цуглуулж бүлэглэл байгуулдгийг чинь хэлж байна). Одоо хэрцгий догшин байх өдрүүд чинь эцэс болж, Би бага багаар чамтай тооцоо бодож байна; хийсэн зүйлээс чинь өчүүхэн жижгийг ч Би зүгээр өнгөрөөхгүй. Одоо эрх мэдлийг авсан нь Сатан чи биш; харин Би тэр эрх мэдлийг буцааж авсан бөгөөд чамтай харьцуулахаар Өөрийн хөвгүүдийг дуудах цаг нь иржээ. Чи өчүүхэн ч эсэргүүцэхгүй, дуулгавартай дагах ёстой. Өмнө нь Миний өмнө хэчнээн сайхан аашилж байсан чинь хамаагүй, тэр чинь өнөөдөр чамд туслахгүй. Хэрвээ чи Миний хайрладаг хүмүүсийн нэг биш бол Би чамайг хүсэхгүй. Нэгээр хэтрүүлэх нь хүлээн зөвшөөршгүй; Миний урьдчилан тогтоосон тоо байх ёстой бөгөөд нэгээр цөөдүүлэх нь бүр ч дор. Сатан, бүү саад хийдэг бай! Би хэнийг хайрлаж, хэнийг үзэн яддагаа зүрх сэтгэлдээ тодорхой мэддэггүй байж таарах уу? Надад чи сануулах хэрэгтэй гэж үү? Сатан Миний хөвгүүдийг төрүүлж чадах уу? Бүгд утгагүй юм! Бүгд олиггүй амьтад! Би бүгдийг нь нэг бүрчлэн, бүрэн дүүрэн хаях болно. Нэг нь ч хэрэггүй; бүгд зайлах ёстой! Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө төгсгөлдөө ирж, Миний ажил дууссан бөгөөд Би адгуус, араатны энэ сүргийг зайлуулах ёстой!

Миний үгэнд итгэж, Миний үгийг хэрэгжүүлдэг хүмүүс нь Миний хайрладаг хүмүүс байх ёстой; Би ганцыг нь ч орхихгүй, нэгийг нь ч тавьж явуулахгүй. Иймээс ууган хөвгүүд болох хүмүүс санаа зовох хэрэггүй. Үүнийг Би хайрласан учир хэн ч үүнийг булаан авч чадахгүй, Би Өөрийн ерөөдөг хүмүүст үүнийг хайрлах учиртай. Өөрийн сайшаадаг хүмүүсийг (дэлхийг бүтээхээс өмнө) Би (өнөөдөр) ерөөдөг. Энэ бол Миний ажилладаг арга зам, мөн Миний захиргааны зарлигийн заалт бүрийн

цаад гол зарчим бөгөөд хэн ч үүнийг өөрчилж чадахгүй; нэг үг ч нэмж болохгүй, бас нэг өгүүлбэр ч, бүр ганц ч үг, өгүүлбэр гээж болохгүй. Өмнө нь Би, та нарт Миний үнэн бие гарч ирнэ гэж байнга хэлдэг байсан. Тэгвэл Миний “үнэн бие” гэж юу вэ, хэрхэн гарч ирдэг вэ? Энэ нь зүгээр л хүн болох Намайг хэлдэг юм уу? Зүгээр л Миний хэлдэг өгүүлбэр бүрийг хэлж байна уу? Энэ хоёр тал хэдийгээр зайлшгүй шаардлагатай боловч өчүүхэн хэсгийг л бүрдүүлдэг; өөрөөр хэлбэл, энэ нь Миний үнэн биеийн талаарх бүрэн гүйцэд тайлбарыг агуулдаг. Миний үнэн биед Миний махбод, Миний үг, бас Миний үйл хэрэг багтдаг боловч хамгийн оновчтой тайлбар бол Миний ууган хөвгүүд болон Би бол Миний үнэн бие юм. Өөрөөр хэлбэл, хаанчилж, эрх мэдэл атгадаг нэгдмэл бүлэг Христэд итгэгч бол Миний үнэн бие билээ. Иймд, ууган хөвгүүдийн нэг бүр нь зайлшгүй шаардлагатай, Миний үнэн биеийн нэг хэсэг учраас цаашид хүмүүсийн тоо нэгээр хэтэрсэн (тийнхүү Миний нэрийг шившиглэж), эсвэл бүр ч чухал нь, нэгээр цөөн ч (тийнхүү Миний бүрэн илрэл болж чадахгүй) байж болохгүй гэдгийг Би онцолдог. Түүнчлэн, ууган хөвгүүд бол Миний хамгийн эрхэм хүмүүс, Миний эрдэнэ, Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний биежилт гэдгийг ахин дахин онцолдог; зөвхөн тэд л Миний төгс, бүрэн илрэл болж чаддаг. Би Өөрөө Өөрийнхөө үнэн биеийн бүрэн илрэл л байж чадна; зөвхөн ууган хөвгүүдийн хамтаар л төгс агаад бүрэн илрэл байдаг гэж хэлж болно. Иймээс аливааг орхигдуулалгүйгээр ууган хөвгүүддээ Би хатуу шаардлага тавьж, Өөрийн ууган хөвгүүдээс бусад бүх хүнийг ахин дахин тастаж, алдаг; энэ бол Миний хэлсэн бүхний үндэс, Миний хэлсэн бүхний эцсийн зорилго билээ. Түүнчлэн, тэд Миний сайшаасан хүмүүс, мөн дэлхийг бүтээснээс хойш Миний биечлэн сонгосон хүмүүс байх ёстой гэдгийг Би ахин дахин онцолдог. Тэгвэл “гарч ирэх” гэдэг үгийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Энэ нь хүн сүнсний ертөнц рүү орох цаг үеийн тухай юу? Ихэнх хүн, энэ бол Миний махбодын тослогдсон цаг, эсвэл Миний махбодыг харсан цаг нь гэж итгэдэг боловч энэ бүгд худал; бүр дөхөж ч очихгүй. Анхдагч утгынх нь дагуу бол “Гарч ирэх” гэдэг нь ойлгоход хэцүү зүйл огтоос биш, харин Миний санаа зорилгын дагуу үүнийг ойлгох нь хамаагүй илүү хэцүү. Би хүн төрөлхтнийг бүтээхдээ, Өөрийн хэв чанарыг Өөрийн хайрладаг энэ бүлэг хүнд нэмж байсан бөгөөд энэ бүлэг хүн Миний үнэн бие байсан гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, Миний үнэн бие тэр үед хэдийнээ гарч ирсэн байсан. Энэ нэрийг хүлээж авсны дараа Миний үнэн бие гарч ирсэн юм биш; харин ч энэ бүлэг хүнийг Би урьдчилан тогтоосны дараа гарч ирсэн, учир нь тэд Миний хэв чанарыг агуулж байсан (тэдний уг чанар өөрчлөгддөггүй, тэд Миний үнэн биеийн нэг хэсэг хэвээр байгаа). Иймд, дэлхийг бүтээсэн цагаас одоог хүртэл Миний үнэн бие үргэлж гарч ирж байсан. Ихэнх хүн, Миний махбод бол Миний үнэн бие гэх үзэлд итгэдэг ч энэ нь огтоос тийм биш; тийм санаа тэдний бодол, үзлээс л төрөн гардаг. Хэрвээ Миний махбод дангаараа Миний үнэн бие байсан бол Сатаныг шившиглэхэд хангалтгүй байх байлаа. Энэ нь Миний нэрийг алдаршуулж чадахгүй байх байсан бөгөөд үнэн хэрэгтээ эсрэг нөлөө үзүүлж, улмаар Миний

нэрийг шившиглэж, эрин үеүдийн туршид Сатан Намайг шившиглэсний тэмдэг болох байсан билээ. Би бол ухаалаг Бурхан Өөрөө бөгөөд Би хэзээ ч тийм тэнэг зүйл хийхгүй байсан.

Миний ажлаас үр дүн гарах ёстой, түүнчлэн Би үгээ арга барилтайгаар ярих ёстой; бүх үг болон айлдвар минь Миний Сүнстэй хамт хэлэгддэг, Өөрийн Сүнсний хийдэг бүхний дагуу Би ярьдаг. Иймээс, Миний үгээр дамжуулан бүгд Миний Сүнсийг мэдэрч, Миний Сүнс юу хийж байгааг харах ёстой; Би яг юу хийхийг хүсдэгийг тэд харж, Миний үгэнд үндэслэж ажиллах арга барилыг минь, Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний зарчмууд юу болохыг харах хэрэгтэй. Би орчлон ертөнцийн дүр зургийг бүхэлд нь ажигладаг: Хүн бүр, үйл явдал болгон, газар нутаг бүр бүгд Миний тушаал дор байдаг. Миний төлөвлөгөөг зөрчиж зүрхлэх хэн ч байдаггүй; бүгд Миний зааварчилсан дарааллаар алхам алхмаар урагшилдаг. Энэ бол Миний сүр хүч; Миний бүхий л төлөвлөгөөг удирдах мэргэн ухаан энд оршдог. Хэн ч бүрэн ойлгож, тодорхой ярьж чадахгүй; Би бүгдийг биечлэн хийж, ганцаараа хянадаг.

106-Р БҮЛЭГ

Миний үгийг, Миний хэвийн хүн чанарыг мэддэггүй, Миний бурханлаг чанарыг эсэргүүцдэг хүмүүс бүгд оргүй хоосон болж бут ниргүүлнэ. Хэн ч үүнээс чөлөөлөгдөхгүй, бүгд энэ талаараа стандарт шаардлагад нийцэж байх ёстой, учир нь энэ бол Миний захиргааны зарлиг, хэрэгжүүлэх ёстой хамгийн ноцтой нь билээ. Миний үгийг мэддэггүй хүмүүс бол Миний тодорхой хэлж өгсөн зүйлийг сонссон атлаа тэдгээрийн талаар ямар ч мэдлэггүй л байдаг хүмүүс; өөрөөр хэлбэл, тэд бол сүнслэг хэрэг явдлыг ойлгодоггүй хүмүүс юм (Би сүнслэг хэрэг явдалд нийцсэн хүний чадвар бүтээгээгүй тул тэднээс ихийг шаарддаггүй; Би тэднээс ердөө л Миний үгийг сонсож, тэдгээрийг хэрэгжүүлж чаддаг байхыг шаарддаг). Тэд бол Миний гэрийн хүмүүс биш, Надтай адил төрлийнх ч биш; тэд Сатаны ертөнцөд харьяалагддаг. Иймээс сүнслэг хэрэг явдлыг ойлгодоггүй энэ хүмүүсийн ганцыг нь ч Би хүсдэггүй. Өмнө нь та нар Намайг хэтрүүлсэн гэж бодсон, гэвч одоо бол та нар ойлгож байх ёстой. Араатнууд яаж Бурхантай ярилцаж чадах юм бэ? Утгагүй хэрэг биш гэж үү? Миний хэвийн хүн чанарыг мэддэггүй хүмүүс бол Өөрийн хүн чанараар юу хийдгийг минь хэмжихдээ өөрсдийн үзлийг ашигладаг хүмүүс юм. Захирагдахын оронд тэд махан биеийн нүдээрээ Намайг өөлөх гэж ирдэг. Магадгүй хэлсэн үг минь хий дэмий байв уу? Миний хэвийн хүн чанар бол бүрэн төгс Бурхан Өөрөө болох Миний зайлшгүй шаардлагатай хэсэг бөгөөд Миний хэвийн хүн чанар болоод бүрэн төгс бурханлаг чанар хоёр бие биетэйгээ хамтран ажиллаж байгаа нь зүй ёсны зам гэж Би хэлсэн: Хэвийн хүн чанарааараа дамжуулан Миний хийдэг зүйл хүний үзэлтэй нийцэхгүй байх үед Намайг эсэргүүцдэг, Надтай нийцдэггүй хүмүүс

илчлэгддэг. Дараа нь хүн чанараар дамжуулан Миний бүрэн төгс бурханлаг чанар ярьж, ийм маягаар Би зарим хүнийг зохицуулсан. Хэрвээ чи Миний юу хийдгийг ойлгодоггүй ч гэсэн захирагддаг бол чи Миний ялладаггүй төрлийн хүн байна; Би ийм хүмүүсийг зүгээр л гэгээрүүлдэг. Би ийм хүмүүсийг хайрладаг бөгөөд захирагддаг болохоор чинь Би чамайг гэгээрүүлдэг. Миний бурханлаг чанарыг эсэргүүцдэг хүмүүст, Миний үгийг мэддэггүй, Миний хэвийн хүн чанартай нийцдэггүй, бурханлаг чанараараа хийдэг зүйлийг (жишээлбэл, Миний уурлаж байгааг эсвэл чуулган барьж байгааг гэх мэт) минь сайшаадаггүй хүмүүс багтдаг. Эдгээр нь бүгд Миний бурханлаг чанарыг эсэргүүцэж байгаагийн илэрхийлэл юм. Гэхдээ Миний онцолдог нэг зүйл бий бөгөөд та нар дор бүрнээ анхаарал хандуулах хэрэгтэй: Өнөөгийн Миний үнэн биетэй нийцдэггүй хүмүүс Миний бурханлаг чанарыг эсэргүүцэж байгаа. Яагаад Би, Миний үнэн бие бол бүрэн төгс Бурхан Өөрөө гэж хэлсээр байгаа вэ? Миний үнэн биеийн зан чанар бурханлаг зан чанарыг бүхэлд нь агуулдаг; Намайг хэмжихдээ хүний үзлийг бүү ашигла. Одоо ч гэсэн, Намайг хэвийн хүн чанартай, Миний хийдэг зүйл заавал бүгд зөв байх албагүй гэж хэлсээр байдаг олон хүн бий. Хүмүүс ингээд байвал чи зүгээр л үхэхийг хүсэж хэрэг биш гэж үү? Тэд Миний хэлж байгаа зүйлээс ганц ч үг мэддэггүй, тэд бол гарцаагүй сохруудын үр удам, агуу улаан лууны үр төл юм! Би бүгдэд нь дахин нэг удаа хэлье (Би дараа нь дахиж хэлэхгүй, энэ зөрчлийг дахин үйлдсэн бүхэн гарцаагүй хараагдана): Миний үг, Миний инээд, Миний идэж байгаа, Миний амьдарч байгаа, Миний үг яриа, Миний зан авир бүгдийг нь Би—Бурхан Өөрөө—хийдэг, үүн дотор холилдсон хүн чанарын өчүүхэн ч ул мөр байхгүй. Юу ч байхгүй! Огтхон ч байхгүй! Хүмүүс бүгд оюун ухааны тоглоом тоглохоо больж, ялихгүй тооцооллоо зогсоох ёстой. Хүмүүс үүнийгээ үргэлжлүүлэх тусам, улам үйл нь ирнэ. Миний зөвлөгөөг анхаар!

Би үргэлж хүн бүрийн зүрх сэтгэлийн гүнийг, хувь хүн болгоны үг, үйлдэл бүрийг шинжилж байна. Би Өөрийн дуртай болон дургүй хүмүүсийг нэг нэгээр нь тодорхой хардаг. Энэ бол хүмүүсийн төсөөлж чадахгүй, түүнчлэн тэдний гүйцэлдүүлж чадахгүй зүйл юм. Би маш ихийг хэлж, маш олон зүйл хийсэн; Миний үг болон Миний хийдэг зүйл зорилго нь юу болохыг хэн тодорхойлж чадах вэ? Хэн ч чадахгүй. Үүнээс хойш, Би илүү их үг хэлэх болно; нэг талаас энэ нь Миний дургүй бүх хүнийг таягдан хаяж, нөгөө талаас энэ тал дээр та нарыг бага зэрэг зовооно, ингэснээр та нар дахин амиллыг дахиад нэг удаа бүр илүү хүчтэйгээр амсах болно. Хүмүүс үүнийг тодорхойлж чадахгүй, хэн ч үүнийг тохиолдохоос нь сэргийлж чадахгүй. Та нар үүнийг одоо мэддэг байлаа ч цаг нь ирэхэд иймэрхүү зовлонгоос мултарч чадахгүй л байх болно, учир нь энэ бол Миний ажлын арга барил. Би Өөрийн зорилгод хүрэхийн тулд, Өөрийн хүслийг та нар дээр биелүүлэх боломжтой болохын тулд ингэж ажиллах ёстой. Ийм учраас үүнийг “та нарын туулах ёстой хамгийн сүүлийн зовлон” гэж нэрлэдэг. Үүний дараа та нарын махан бие үүнээс хойш дахин хэзээ ч зовохгүй, учир нь Би агуу улаан лууг хүйс тэмтэрсэн байх бөгөөд тэр дахин үймээн самуун гаргаж зүрхлэхгүй. Энэ бол биед орохын өмнөх

эцсийн алхам; шилжилтийн үе шат. Гэвч бүү ай, Би та нарыг бэрхшээл бүрийн дундуур залж чиглүүлэх нь гарцаагүй. Намайг зөвт Бурхан Өөрөө гэдэгт, Миний хэлдэг зүйл гарцаагүй биелнэ гэдэгт итгэ. Би бол итгэлт Бурхан Өөрөө. Бүх улс, бүх газар нутаг, бүх урсгал Над руу эргэн ирж, Миний сэнтийд хуран цуглаж байна. Энэ бол Миний агуу хүч, Би хэнийг ч орхилгүйгээр, тэрслүү хүүхэд бүрийг шүүж, гал, хүхрийн нуур луу хаяна. Бүгд ухрах ёстой. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний эцсийн алхам бөгөөд үүнийг дуусахад Би амралтын байдалд орох болно, учир нь бүх зүйл хийгдчихсэн, Миний удирдлагын төлөвлөгөө төгсгөлдөө очсон байх болно.

Миний ажлын хурд нэмэгдсэн учир (хэдийгээр Би огт түгшихгүй байгаа ч) Би Өөрийн үгийг та нарт өдөр бүр илчилж, Өөртөө хадгалдаг нууцуудыг өдөр бүр дэлгэнэ, ингэснээр та нар Миний хөлийн алхааг ойрхон дагаж чадна. (Энэ бол Миний мэргэн ухаан; Би хүмүүсийг төгс болгож, бас тэднийг цохин унагахаар Өөрийн үгийг ашигладаг. Бүгд Миний үгийг уншиж, Миний үгэн дэх Миний хүслийн дагуу үйлдэж чаддаг. Сөрөг хүмүүс сөрөг болж, илчлэгдэх хүмүүс нь үнэн дүр төрхөө харуулах болно; зөрүүд хүмүүс эсэргүүцэж, Намайг үнэнчээр хайрладаг хүмүүс улам илүү үнэнч болох болно. Ийм учраас, бүгд Миний хөлийн алхааг дагаж чадна. Миний дүрсэлсэн эдгээр нөхцөл байдал бүгд Миний ажилладаг арга барил, Миний хүрэхийг хүсдэг зорилго юм.) Өмнө нь Би иймэрхүү зүйл хэлсэн: Би та нарыг яаж удирдан чиглүүлнэ, та нар тийм байдлаар эрж хайх хэрэгтэй; Би та нарт юу ч хэлсэн, та нар сонсох хэрэгтэй. Би үүгээрээ юу хэлэх гээд байна вэ? Та нар мэдэх үү? Миний үгийн зорилго, ач холбогдол юу вэ? Та нар ойлгож байна уу? Хэчнээн хүн үүнийг бүрэн дүүрэн илэрхийлж чадах вэ? “Би та нарыг яаж удирдан чиглүүлнэ, та нар тийм байдлаар эрж хайх хэрэгтэй” гэж хэлэхдээ Миний үнэн бие Өөрийн залж чиглүүлж байгааг хэлж байгаа төдий юм биш; үүнээс гадна Өөрийн хэлдэг үг, явдаг замыг хэлж байгаа юм. Өнөөдөр, эдгээр үг үнэхээр биелсэн. Намайг үгээ хэлмэгц бүх төрлийн чөтгөрийн царай Миний гэрлийн өмнө ил болж, та нарт тэднийг бүгдийг нь тодорхой харуулдаг. Миний энэхүү айлдварууд зөвхөн Сатанд хандсан мэдэгдэл биш, харин та нарт бүгдэд нь өгсөн даалгавар юм. Эдгээр үгийг өөрсдөд чинь өгсөн даалгавар гэж итгэн та нарын ихэнх нь үүнийг үл тоодог; эдгээр нь шүүлтийн үг, эрх мэдэл агуулдаг үг гэдгийг та нар ухаардаггүй. Миний үгийн зорилго бол Надад зүй ёсоор үйлчлэл хийж, бүрэн дүүрэн захирагдахыг Сатанд тушаах явдал юм. Өнгөрсөнд, Миний илчилсэн нууцуудаас, та нарын хараахан ойлгоогүй нь олон бий. Иймээс, ирээдүйд Би та нарт илүү ихийг илчилнэ, ингэснээр та нар илүү тодорхой, нэгд нэггүй ойлголтод хүрч чадна.

Гай гамшиг ирэхэд хүн бүр айн балмагддаг. Хүмүүс бүгд гашуудалтайгаар орь дуу тавьж, урьдын хийсэн ёрын муу зүйлсээ жигшдэг ч тэр үед хэдийнээ оройтсон байдаг, учир нь энэ бол уур хилэнгийн эрин үе билээ. Хүмүүсийг аварч, тэдэнд нигүүлсэл өгөх цаг биш, харин бүх үйлчлэл үзүүлэгчийг зайлуулж, Миний төлөө захирах боломжийг хөвгүүддээ олгох цаг юм. Энэ нь өнгөрсөн цаг үеэс үнэхээр өөр;

дэлхийг бүтээснээс хойш үзэгдэж харагдаагүй билээ. Би дэлхийг нэг удаа бүтээсэн учир дэлхийг нэг удаа сөнөөнө, мөн Миний урьдчилан тогтоосон зүйлийг хэн ч өөрчилж чадахгүй. “Нэгдмэл Христэд итгэгч хүмүүс” болон “нэгдмэл орчлон ертөнцийн шинэ хүмүүс” гэх хоёр нэр томьёог өмнө нь нэлээд их дурдаж байсан. Эдгээрийг хэрхэн тайлбарлах хэрэгтэй вэ? “Нэгдмэл Христэд итгэгч хүмүүс” нь ууган хөвгүүдийг хэлдэг үү? “Нэгдмэл орчлон ертөнцийн шинэ хүмүүс” ч бас ууган хөвгүүдийг хэлдэг үү? Үгүй; хүмүүс эдгээр хэллэгийг үнэн зөвөөр тайлбарлаагүй. Хүмүүсийн үзэл аливааг энэ хэмжээнд л ойлгоход тусалж чаддаг учир энд, одоо Би та нарт үүнийг тодруулж өгнө. Нэгдмэл Христэд итгэгч хүмүүс болон нэгдмэл орчлон ертөнцийн шинэ хүмүүс нь ижилхэн биш; тусдаа утгатай. Хэдийгээр энэ хоёр нэр томьёоны үг нь тун төстэй бөгөөд адилхан зүйл шиг санагдаж магадгүй ч үнэн хэрэгтээ шал эсрэг тэсрэг юм. “Нэгдмэл Христэд итгэгч хүмүүс” гэж яг хэнийг хэлдэг вэ? Эсвэл, юуг хэлдэг вэ? Христэд итгэгч хүмүүсийн тухайд яривал, хүн бүр санал нэгтэйгээр Намайг бодно. Ингэх нь тэдний буруу огт биш. Түүнчлэн, хүмүүсийн үзэлд, “хүмүүс” гэдэг нь гарцаагүй хүмүүсийг хэлнэ, нэг ч хүн үүнийг өөр зүйлтэй холбохгүй. “Нэгдмэл” гэх хэллэгийн тухай яривал, энэ нь бараг л нэг юм шиг болсон олон хүний цугларалт, иймээс ч үүнийг “нэгдмэл” гэж нэрлэдэг хэмээн хүмүүс бодно. Эндээс, хүний оюун ухаан дэндүү энгийн гэдгийг харж болно; тэд Миний утгыг огтхон ч ойлгож чаддаггүй. Одоо, Би нэгдмэл Христэд итгэгч хүмүүс гэж юу болох тухай албан ёсоор нөхөрлөж эхлэх болно (харин хүмүүс бүгд өөрсдийн үзлийг хаях ёстой; эс тэгвээс тэдний хэн нь ч үүнийг ойлгож чадахгүй, Би нэр томьёог нь тайлбарласан ч гэсэн, тэд үүнд итгэх ч үгүй, ойлгох ч үгүй): Намайг үгээ хэлмэгц, Миний ууган хөвгүүд бүгд Миний хүсэлд нийцүүлэн үйлдэж, Миний хүслийг илэрхийлж чадах болно, иймээс тэд нэгэн зүрх сэтгэл, нэг амтай юм. Тэд бүх улс үндэстэн, бүх хүнийг шүүж байхдаа, Миний зөвт байдлыг гүйцэтгэж, Миний захиргааны зарлигийг хэрэгжүүлэх чадвартай байна; тэд бол Миний илэрхийлэл, Миний илрэл. Иймээс, нэгдмэл Христэд итгэгч хүмүүс бол ууган хөвгүүд Миний захиргааны зарлигийг хэрэгжүүлж байгаагийн бодит баримт; тэд бол ууган хөвгүүдийн гарт буй эрх мэдэл гэж хэлж болно. Энэ нь бүгд Христтэй холбоотой—тийм ч учраас “Христэд итгэгч хүмүүс” гэдэг нэр томьёо гарсан. Түүнчлэн, бүх ууган хөвгүүн Миний хүслийн дагуу үйлдэж чаддаг, иймээс Би “нэгдмэл” гэх нэр томьёог ашигладаг. “Нэгдмэл орчлон ертөнцийн шинэ хүмүүс” гэдэг нь Миний нэрэн дэх бүх хүн; өөрөөр хэлбэл, Миний ууган хөвгүүд, Миний хөвгүүд, мөн Миний ардууд гэсэн үг юм. “Шинэ” гэдэг үг нь Миний нэртэй хамаатай. Тэд Миний нэрээр байгаа учир (Миний нэр бүхнийг агуулдаг, мөнхөд шинэ, хэзээ ч хуучин биш; үүнийг хүн өөрчлөхийн аргагүй), ирээдүйд үүрд амьд байх учраас, тэд бол орчлон ертөнцийн шинэ хүмүүс юм. Энд байгаа “нэгдмэл” гэдэг үг нь хүмүүсийн тоотой хамаатай бөгөөд өмнөх тохиолдолтой ижил биш. Намайг үгээ хэлэхэд бүгд үүнд итгэх хэрэгтэй. Бүү эргэлз. Хүний үзэл, бодлоосоо ангижир. Нууцуудыг илчилж байгаа Миний одоогийн үйл явц бол хүмүүсийн үзэл, бодлыг авч хаях яг тэр үйл явц юм

(хүмүүс Намайг болон Миний хэлдэг зүйлийг хэмжихдээ өөрсдийн үзлийг ашигладаг учраас хүмүүсийн үзэл, бодлыг авч хаяхдаа Би Өөрийн илчлэгдсэн нууцуудыг ашигладаг). Энэ ажил удахгүй гүйцэлдэнэ. Миний нууцууд тодорхой хэмжээнд илчлэгдэх үед, хүмүүс Миний үгийг бодож боловсруулахаа бараг больж, хүний үзлээрээ Намайг хэмжихээ болино. Тэдний өдөр бүр боддог юмыг Би илчилж, хариу цохилт өгнө. Тодорхой цэгт, хүмүүс бодохоо болино; толгойд нь бүх бодол үгүй болж хоосорч, Миний үгэнд бүрэн захирагдана. Тэр үед та нар сүнсний ертөнцөд орно. Би та нарт сүнсний ертөнцөд орох боломж олгохын өмнөх Миний ажлын алхам энэ юм. Та нар ариун агаад өө сэвгүй болж, сүнсний ертөнцөд орохоосоо өмнө хүний үзлээсээ ангижрах ёстой. “Би бол ариун сүнслэг бие” гэдгээр үүнийг хэлж байгаа юм. Гэхдээ, та нар Миний алхмуудтай нийцүүлэн үйлдэх ёстой бөгөөд та нарыг ухаарахаас өмнө Миний цаг ирэх болно.

107-Р БҮЛЭГ

Миний үг тодорхой түвшинд хатуу ширүүн болох үед тэдгээрээс болж ихэнх хүн ухарч няцдаг—яг энэ мөчид Миний ууган хөвгүүд илчлэгддэг. Би бүх зүйлийг биелүүлэхдээ хуруугаа ч хөдөлгөдөггүй, харин зөвхөн Өөрийн үгийг л ашигладаг гэдгээ хэлсэн. Үгээрээ Би Өөрийн үзэн яддаг бүхнийг устгадаг, мөн Би Өөрийн ууган хөвгүүдийг төгс болгохдоо тэдгээрийг ашигладаг. (Намайг үг хэлэхэд долоон аянга нүргэлж, тэр мөчид Миний ууган хөвгүүд болон Би хэлбэрээ өөрчилж, сүнсний ертөнцөд орно.) Миний Сүнс биечлэн ажилладаг гэж хэлэхдээ Би, Миний үг бүхнийг биелүүлдэг гэдгийг хэлсэн бөгөөд Би бол төгс хүчит гэдэг нь үүнээс илэрхий байна. Иймд, Миний айлддаг өгүүлбэр бүрийн цаад зорилго, зорилтыг хүн бүр ч илүү тодорхой харж чадна. Би өмнө нь хэлсэнчлэн, Өөрийн хүн чанарын дотор хэлдэг бүхэн минь Миний илрэлийн нэг тал билээ. Тиймээс, Өөрийн хэвийн хүн чанар дотор хэлдэг зүйлд минь итгэлтэй биш, бас үнэхээр итгэдэггүй тэр хүмүүсийг авч хаях ёстой! Миний хэвийн хүн чанар бол Миний бүрэн төгс бурханлаг чанарын зайлшгүй шаардлагатай нэг тал гэдгийг Би удаа дараа онцолсон боловч маш олон хүн одоо ч Миний бүрэн төгс бурханлаг чанарт л анхааран, Миний хүн чанарыг үл хэрэгсдэг. Та нар сохор юм! Би үзэлтэй чинь нийцдэггүй, мөн хүн болох Би, Бурхантай чинь нийцдэггүй гэж чи хэлдэг. Энэ хүмүүс Миний хаанчлалд үлдэж чадах уу? Би чамайг хөл доороо дэвсэлнэ! Чи цаашид Миний эсрэг тэрслээд үзээрэй! Ийм дурааараа байгаад үзээрэй! Миний инээмсэглэл чамд байдаг үзэлтэй нийцдэггүй, Миний яриа чиний чихэнд чимэггүй, Миний үйлдэл чамд ашиг тусгүй, тийм биз? Энэ бүх зүйл чиний таалалд нийцэх ёстой. Бурхан тийм байдаг гэж үү? Тэгээд энэ хүмүүс Миний гэрт үлдэж, Миний хаанчлалд ерөөл хүртэхийг хүссээр байдаг гэж үү? Чи сэрүүн зүүдэлж байгаа юм биш үү? Хэзээнээс юм тийм гайхалтай байдаг байлаа даа! Надад дуулгаваргүй байхыг хүсдэг атлаа Надаас ерөөл хүртэхийг хүсдэг. Би чамд хэлье:

Яасан ч үгүй! Миний олон удаа хэлсэнчлэн, Миний хаанчлалд орж, ерөөл хүртдэг хүмүүс Миний хайрладаг хүмүүс байх ёстой. Яагаад Би энэ үгийг онцолдог вэ? Хүн бүр зүрх сэтгэлдээ юу бодож байгааг Би мэддэг, ойлгодог; тэдний бодлыг Би нэг нэгээр нь хэлж өгөх шаардлагагүй. Тэдний жинхэнэ төрх Миний шүүлтийн үгээр дамжин илчлэгдэх бөгөөд Миний шүүх суудлын өмнө бүгд гашуудалтайгаар орь дуу тавина. Энэ бол хэн ч өөрчилж чадахгүй илэрхий баримт! Эцэст нь, Би тэднийг ёроолгүй нүхэнд нэг нэгээр нь оруулна. Энэ бол диавол Сатаныг шүүхдээ Миний хүрэхийг хүсдэг эцсийн үр дүн юм. Би хүн бүрд хандахдаа шүүлт болон захиргааны зарлигийг ашиглах ёстой бөгөөд Би хүмүүсийг ингэж гэсгээдэг. Та нарт энэ тухай жинхэнэ ойлголт бий юу? Би Сатанд шалтаг өгөх шаардлагагүй; харин түүнийг амь мөлтөс үлдэн, ахин дахин өршөөл гуйх хүртэл нь жанчихын тулд зүгээр л төмөр саваагаа ашигладаг. Тиймээс хүмүүс Миний шүүлтийн үгийг уншаад өчүүхэн ч ойлгож чаддаггүй, харин Миний өнцгөөс бол мөр болгон нь, мөн өгүүлбэр бүр нь Миний захиргааны зарлигийн хэрэгжилт юм. Энэ бол илэрхий баримт.

Өнөөдөр Би шүүлтийг дурдсан тул энэ сэдэв шүүх суудлыг хөндөж байна. Та нар Христийн суудлын өмнө шүүлт хүлээн авна гэж өмнө нь үргэлж хэлдэг байсан. Шүүлтийн талаар та нарт зарим нэг ойлголт байдаг боловч шүүх суудлыг төсөөлж чаддаггүй. Магадгүй, зарим хүн шүүх суудлыг биет эд зүйл гэж бодож, том ширээ мэтээр төсөөлж, эсвэл шашны бус ертөнцөд байдаг шүүгчийн суудал шиг төсөөлдөг. Мэдээж, Би энэ удаад, Өөрийн тайлбарт та нарын хэлснийг үгүйсгэхгүй боловч Миний хувьд хүмүүсийн төсөөлөл дэх зүйлс бэлгэдлийн утга агуулсаар байдаг. Иймд, хүмүүсийн төсөөлдөг зүйл болон Миний хэлэх гээд байгаа зүйл хоёрын хоорондох ангал тэнгэр, газрын хоорондох шиг өргөн. Хүмүүсийн үзлээр бол шүүх суудлын өмнө нүүрээрээ газар унан мөргөж, гашуудалтайгаар орь дуу тавьж, өршөөл гуйж буй олон хүн бий. Үүнд хүний төсөөлөл аль хэдийнээ оргилдоо хүрсэн бөгөөд үүнээс илүүг төсөөлж чадах хэн ч үгүй. Тэгвэл шүүх суудал гэж юу вэ? Намайг энэхүү нууцыг дэлгэхээс өмнө та нар өмнөх бүх буруу ойлголтоосоо татгалзах ёстой: тэгсэн цагт л Миний зорилго биелж чадна. Энэ сэдвийн талаарх та нарын үзэл, санаа бодлыг арилгаж чадах цорын ганц зам нь энэ. Та нар Намайг ярих болгонд анхаарал хандуулах ёстой. Хайхрамжгүй байхаа болих ёстой. Дэлхийг бүтээснээс хойш Миний шүүх суудал байгуулагдсан юм. Өнгөрсөн эрин үеүдэд, үеийн үед Миний шүүх суудлын өмнө олон хүн үхэж, олон хүн өндийн босож, эргэн амь орсон. Эхнээсээ төгсгөл хүртэл Миний шүүлт хэзээ ч зогсдоггүй учраас Миний шүүх суудал үргэлж оршдог гэж хэлж болно. Шүүх суудлыг дурдах болгонд, хүмүүст бүгдэд нь айдсын ул мөр мэдэрдэг. Мэдээж, Миний дээр хэлснээс үзвэл та нар шүүх суудал гэж юу болохыг огт мэддэггүй. Шүүх суудал шүүлттэй зэрэгцэн оршдог боловч тэдгээр нь хоёр гол чанартай. (Энд “гол чанар” гэдгээр биет объект биш, харин үгийг хэлдэг. Хүмүүс энэхүү гол чанарыг огт харж чаддаггүй.) Шүүлт гэдэг нь Миний үг юм. (Тэдгээр нь хатуу ч бай, зөөлөн ч бай, бүгд Миний шүүлтэд багтсан байдаг. Иймд, Миний амнаас гардаг юу ч бай шүүлт юм.)

Өмнө нь, Миний үгийг хүмүүс шүүлтийн үг, зөөлөн үг, амиар хангадаг үг зэрэг олон өөр ангилалд хуваадаг байсан. Шүүлт болон Миний айлдвар нь нэг нэгэнтэйгээ холбоотой гэдгийг Би өнөөдөр та нарт тодруулъя. Өөрөөр хэлбэл, шүүлт бол Миний үг, Миний үг бол шүүлт; та нар эдгээрийг тус тусад нь ярьж огт болохгүй. Хүмүүс хатуу үг бол шүүлт гэж төсөөлдөг боловч, ойлголт нь дутуу хагас байдаг. Миний хэлдэг бүхэн шүүлт. Өмнө нь хэлсэн шүүлтийн эхлэл гэдэг нь Миний Сүнс албан ёсоор газар бүрд ажиллаж, Миний захиргааны зарлигийг хэрэгжүүлж эхэлснийг хэлдэг. Энэ өгүүлбэрт, “шүүлт” гэдэг нь жинхэнэ бодит байдлыг хэлж байна. Одоо Би шүүх суудлыг тайлбарлая: Шүүх суудал үүрдийн үүрд оршиж, Миний шүүлттэй хамт явдаг гэж Би яагаад хэлдэг вэ? Та нар шүүлтийн тухай Миний тайлбараас энэ талаар зарим нэг ойлголт олж авсан уу? Шүүх суудал гэдэг нь хүн болох Намайг хэлдэг. Үүрдийн үүрд Би үргэлж үг хэлж, ярьж байдаг. Би үүрд амьдардаг учир Миний шүүх суудал болон Миний шүүлт үүрд зэрэгцэн оршино. Одоо бол энэ тодорхой байх учиртай! Хүмүүс төсөөлөлдөө Надад эд зүйл мэтээр ханддаг ч энэ тал дээр Би та нарыг буруутгадаг ч үгүй, бас ялладаг ч үгүй. Би та нарыг дуулгавартай байж, Миний илчлэлийг хүлээн зөвшөөрч, Би бол бүхнийг агуулагч Бурхан Өөрөө гэдгийг үүнээс мэдээсэй гэж л найдна.

Хүмүүст Миний үг огт ойлгомжгүй, Миний мөр олохын аргагүй, Миний хүсэл ухаарахын аргагүй байдаг. Иймээс та нарын өнөөдөр байгаа байдал (Миний илчлэлийг хүлээн авч, үүн дотроос Миний хүслийг ухаарч, үүгээр дамжуулан Миний мөрийг дагаж чаддаг байх) бол бүхэлдээ Миний гайхамшигт үйлдэл, Миний нигүүлсэл, Миний энэрлийн үр дүн юм. Нэг л өдөр, Би та нарт Өөрийн мэргэн ухааныг ч харуулж, Өөрийн гараар юу хийснээ үзүүлж, Өөрийн ажлын гайхамшгийг харуулна. Тэр цаг ирэхэд Миний бүхэл бүтэн удирдлагын төлөвлөгөөний зураг төсөл та нарын нүдний өмнө бүрэн илчлэгдэнэ. Орчлон ертөнц даяар, өдөр бүр, Миний гайхамшигт үйлдлийн зарим хэсэг илэрч, Миний удирдлагын төлөвлөгөөг биелүүлэхийн тулд бүгд үйлчлэл үзүүлж байна. Энэ нь бүрэн дүүрэн илчлэгдэхэд, Би ямар хүмүүсээр үйлчлэл хийлгэж, ямар хүмүүсээр Өөрийн хүслийг биелүүлэхээр зохицуулж, Сатаныг ашиглах замаар юунд хүрсэн, Би Өөрөө юуг биелүүлсэн, ямар төрлийн хүмүүс уйлж, ямар төрлийн хүмүүс шүдээ хавирч байгаа, ямар төрлийн хүмүүс сүйрч, ямар төрлийн хүмүүс мөхөхийг та нар харах болно. Би “сүйрэл” гэдгээр хүхэртэй галт нууранд хаягдаж, бүрмөсөн шатах хүмүүсийг; “мөхөл” гэдгээр ёроолгүй нүхэнд хаягдаж мөнхөд зовж шаналах хүмүүсийг хэлдэг. Иймээс сүйрэл, мөхөл хоёрыг нэг зүйл гэж бүү эндүүр; харин ч эсрэгээрээ энэ хоёр маш өөр. Өнөөдөр Миний нэрийг орхидог үйлчлэл үзүүлэгчид мөхөх бол, Миний нэрийнх биш хүмүүс сүйрэх болно. Ийм учир, мөхөгсөд Миний шүүлтийн дараа Надад мөнхийн магтаал өргөх болно; гэсэн ч тэр хүмүүс хэзээ ч Миний гэсгээлтээс ангижрахгүй, Миний захиралтыг үргэлж хүлээн авах болно гэж Би хэлдэг. Ийм учраас ёроолгүй нүх бол хүмүүсийг гэсгээхдээ Миний ашигладаг гар гэж Би хэлдэг. Мөн Би бүх зүйл Миний гарт байгаа гэж хэлдэг. Хэдийгээр

“ёроолгүй нүх” гэдэг нь Сатаны нөлөөг хэлдэг гэж Би хэлсэн боловч энэ нь бас Миний гарт байдаг бөгөөд хүмүүсийг гэсгээхдээ Би үүнийг ашигладаг. Иймд, бүх зүйл Миний гарт байдаг гэж Намайг хэлэхэд зөрчилдөх зүйл үгүй. Миний үг хариуцлагагүй биш; Энэ нь зүй ёсны, авцалдаатай байдаг. Үүнийг зохиогоогүй, мөн утга учиргүй ч биш бөгөөд хүн бүр Миний айлдварт итгэх ёстой. Ирээдүйд, та нар үүнээс болж зовно. Миний үгээс болж олон хүн цэвдэг болж, цөхөрч, урам нь хугарч, гашуудан орь дуу тавьж, уйлдаг. Бүх төрлийн хариу үйлдэл байх болно. Нэг л өдөр, Миний үзэн яддаг бүх хүн ухарч няцахад Миний агуу ажил гүйцэлдэнэ. Ирээдүйд, ууган хөвгүүдээс болж олон хүн унах бөгөөд эцэстээ тэд алхам алхмаар явах болно. Өөрөөр хэлбэл, Миний гэр аажмаар ариун болж, бүх төрлийн чөтгөр Миний дэргэдээс аажмаар ухарч, чимээгүй, дуулгавартайгаар, гомдлын ганц ч үггүйгээр явна. Үүний дараа Миний ууган хөвгүүд бүгд илчлэгдэж, Би Өөрийн ажлын дараагийн алхмыг эхэлнэ. Тэр үед л ууган хөвгүүд Надтай хамт хаан болж, бүхий л орчлон ертөнцийг захирах болно. Эдгээр нь Миний ажлын алхам бөгөөд Миний удирдлагын төлөвлөгөөний чухал хэсгийг бүрдүүлдэг. Үүнийг бүү үл тоомсорло; эс бөгөөс чи алдаа гаргах болно.

Миний үг та нарт илчлэгдэх үе нь Би ажлаа эхлэх цаг байдаг. Миний ганц ч үг биелэхгүй үлдэнэ гэж үгүй. Надад, нэг өдөр мянган жил шиг, мянган жил нэг өдөр шиг байдаг. Үүнийг та нар яаж харж байна вэ? Би орчлон ертөнцийг хянаж, бүх зүйлийг бүтээдэг учир цаг хугацааны тухай та нарын ойлголт Минийхээс маш өөр. Миний ажил өдөр өдрөөр, алхам алхмаар, шат шатаар хийгддэг; түүнчлэн, Миний ажил ганц секунд ч зогсолгүй урагшилдаг: Хором бүрд Байнга хийгдэж байдаг. Дэлхий ертөнцийг бүтээснээс хойш Миний үг хэзээ ч тасалдаагүй. Өнөөдрийг хүртэл Би үг хэлж, айлдвараа айлдсаар ирсэн; ирээдүйд ч энэ нь өөрчлөгдөлгүй үлдэх болно. Гэвч, Миний цаг нарийн зохицуулагдаж, зохион байгуулагдсан, маш дэс дараатай. Би Өөрийн хийх хэрэгтэй зүйлийг хийх хэрэгтэй үедээ хийх (Надтай хамт, бүгд чөлөөлөгдөнө; бүгд чөлөөтэй болох болно) бөгөөд Миний ажлын алхмуудын тухайд өчүүхэн ч саатдаггүй. Би Өөрийн гэр дэх хүн бүрийг, дэлхий ертөнц дэх хүн бүрийг зохицуулж чаддаг ч, Миний Сүнс ажиллаж байгаа учир Би огтоос завгүй биш. Миний Сүнс газар бүрийг дүүргэдэг, учир нь Би бол цор ганц Бурхан Өөрөө агаад бүхий л орчлон ертөнц Миний гарт байдаг. Тиймээс Би төгс хүчит, ухаалаг болохыг, мөн Миний алдар суу орчлонгийн өнцөг булан бүрийг дүүргэдэг болохыг хүн харж чаддаг.

108-Р БҮЛЭГ

Миний дотор бүгд амгалан байдлыг олж, бүгд эрх чөлөөнд хүрч чадна. Миний гадна байгаа хүмүүс эрх чөлөөг ч, аз жаргалыг ч олж авч чаддаггүй, учир нь Миний Сүнс энэ хүмүүстэй хамт байдаггүй. Энэ хүмүүсийг сүнсгүй үхдэл гэж нэрлэдэг.

Харин Би Өөрийн доторх хүмүүсийг сүнстэй, амьд хүмүүс гэдэг. Тэд Надад харьяалагддаг бөгөөд Миний сэнтийд эргэн очих заяатай. Үйлчлэл үзүүлдэг хүмүүс болон диаволд харьяалагддаг хүмүүс бол сүнсгүй үхдэлүүд бөгөөд, тэднийг ор мөргүй болгож, устгах ёстой. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний нууц бөгөөд Миний удирдлагын төлөвлөгөөнөөс хүн төрөлхтний ойлгож чаддаггүй нэг хэсэг юм. Гэхдээ Би үүнийг ч бас хүн бүрд ил болгосон. Надад харьяалагддаггүй хүмүүс Миний эсрэг байдаг; Надад харьяалагддаг хүмүүс бол Надтай нийцэлтэй байдаг хүмүүс юм. Үүнд эргэлзэх зүйл огт үгүй бөгөөд энэ бол Миний Сатаныг шүүх шүүлтийн цаад зарчим билээ. Миний зөвт, шударга байдлыг харахын тулд энэ зарчмыг хүн бүр мэдэх хэрэгтэй. Сатанаас гаралтай бүх хүн шүүгдэж, шатаагдан, үнс чандруу болон хувирна. Энэ ч бас Миний уур хилэн бөгөөд үүнээс Миний зан чанар илүү тодорхой харагддаг. Одоогоос эхлэн, Миний зан чанар нээлттэйгээр зарлагдах болно; тэгээд бүх ард түмэн, бүх улс үндэстэн, бүх шашин, бүх урсгал, мөн нийгмийн бүх давхаргад аажмаар илчлэгдэнэ. Юу ч нууцлаг үлдэхгүй, бүгд илчлэгдэх болно. Миний зан чанар болон Миний үйлдлийн цаад зарчим нь хүн төрөлхтний хувьд хамгийн далд нууц учир үүнийг Би хийх ёстой (тэгснээр ууган хөвгүүд Миний захиргааны зарлигийг зөрчихгүй, мөн Миний илчлэгдсэн зан чанарыг ашиглан бүх ард түмэн, улс үндэстнийг шүүх юм). Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөө бөгөөд эдгээр нь Миний ажлын үе шат юм. Хэн ч үүнийг хялбар өөрчлөхгүй. Би аль хэдийн Өөрийн бурханлаг чанарын бүрэн зан чанарыг Өөрийн хүн чанар дотор амьдран харуулсан тул Миний хүн чанарыг уурлуулахыг Би хэнд ч зөвшөөрдөггүй. (Миний амьдран харуулдаг бүхэн бол бурханлаг зан чанар юм. Ийм учраас Би өмнө нь Өөрийгөө хэвийн хүн чанарыг давсан Бурхан Өөрөө гэж хэлсэн.) Намайг уурлуулдаг хэнийг ч бай Би яавч уучлахгүй бөгөөд түүнийг үүрд мөхөөх болно! Санаж яв! Энэ бол Миний шийдсэн зүйл, өөрөөр хэлбэл, энэ бол Миний захиргааны зарлигийн салшгүй хэсэг юм. Хүн бүр үүнийг ойлгох ёстой: Хүн Би бол Бурхан, ялангуяа Бурхан Өөрөө юм. Энэ одоо тодорхой болсон байх учиртай! Би хайхрамжгүй ярьдаггүй. Чамайг бүрэн ойлготол Би бүх зүйлийг тодорхой айлдаж, тайлбарладаг.

Нөхцөл байдал маш түгшүүртэй байна; зөвхөн Миний гэрт бус, Миний гэрийн гадна байхдаа бүр тэр тусмаа, Миний нэрийг гэрчилж, Намайг амьдран харуулж, Намайг бүх талаар гэрчлэхийг Би та нараас шаарддаг. Одоо эцсийн цаг үе учир бүх зүйл бэлэн болж, бүх зүйл анхны төрхөө олсон бөгөөд хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хөсөр хаях учиртайг нь хөсөр хаяж, үлдээх учиртайг нь үлдээнэ. Хүчээр зууралдаж, эсвэл түлхэн холдуулах гэж бүү хичээ. Миний удирдлагад саад болж, Миний төлөвлөгөөг сүйрүүлэх гэж бүү оролд. Хүмүүсийн өнцгөөс бол Би хүн төрөлхтөнд үргэлж элэгсэг, өрөвч нинжин ханддаг, харин Минийхээр бол Миний зан чанар ажлын минь үе шатнаас хамааран ялгагддаг, учир нь Би бол бодит Бурхан Өөрөө, мөн цор ганц Бурхан Өөрөө юм! Би хувиршгүй атлаа үргэлжид өөрчлөгддөг. Энэ бол хэний ч ухан ойлгож чадахгүй зүйл юм. Намайг та нарт үүнийг хэлж,

тайлбарлаж өгөх үед л та нар тодорхой ойлголттой болж, ухаардаг. Би Өөрийн хөвгүүдэд элэгсэг, өрөвч нинжин, зөвт, сахилга баттай ханддаг ч шүүдэггүй (өөрөөр хэлбэл, Би ууган хөвгүүдийг сүйрүүлдэггүй гэсэн үг). Миний хөвгүүдээс бусдад нь бол Би солигдох эрин үеэс шалтгаалан хэдийд ч хамаагүй өөрчлөгддөг: Би, элэгсэг, өрөвч нинжин, зөвт, сүр жавхлант, шүүлттэй, уур хилэнтэй болж, харааж, шатааж, эцэст нь махан биеийг нь сүйрүүлж ч чадна. Сүйрсэн хүмүүс сүнс, сэтгэлийнхээ хамтаар мөхөх болно. Харин үйлчлэл үзүүлдэг хүмүүсийн хувьд, зөвхөн сүнс болон сэтгэлийг нь л үлдээнэ (үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх нарийн ширийнийг дараа та нарт хэлж ойлгуулах болно). Гэвч тэд Миний ард түмний дор, Миний ард түмний хяналт дор байх учир хэзээ ч эрх чөлөөтэй байхгүй бөгөөд хэзээ ч суллагдахгүй. Үйлчлэл үзүүлэгчдийг Би тэгтлээ жигшдэгийн шалтгаан гэвэл тэд бүгд агуу улаан лууны үр удам бөгөөд үйлчлэл үзүүлэгч биш хүмүүс ч бас агуу улаан лууны үр удам байдаг. Өөрөөр хэлбэл, ууган хөвгүүдээс бусад бүх хүн агуу улаан лууны үр удам юм. Мөхөлд орсон хүмүүс Надад мөнхийн магтаал өргөх болно гэж Би хэлдэг нь тэд Надад үүрд үйлчлэл үзүүлнэ гэсэн утгатай. Энэ бол аль хэдийн шийдэгдчихсэн зүйл. Тэр хүмүүс үргэлж боол, үхэр, адуу байх болно. Тэд агуу улаан лууны үр удам бөгөөд Миний зан чанар тэдэнд байхгүй тул тэднийг Би хэдийд ч нядалж, хүссэнээрээ ноёлж чаддаг. Мөн тэд агуу улаан лууны үр удам тул түүний зан чанартай, өөрөөр хэлбэл, адгуусны зан чанартай байдаг. Энэ бол мөнхөд үл өөрчлөгдөх туйлын үнэн юм! Энэ бүгдийг Би урьдчилан тогтоосон тул хэн ч үүнийг өөрчлөх учиргүй (Би хэнд ч энэ дүрмийн эсрэг үйлдэхийг зөвшөөрөхгүй гэсэн үг), хэрэв тэгэхээр оролдвол Би чамайг цохин унагана!

Та нар Миний илчилсэн нууцуудаас Миний удирдлагын төлөвлөгөө болон ажил аль шатанд хүрснийг харах хэрэгтэй. Намайг гараараа юу хийдгийг, ямар хүмүүс дээр Миний шүүлт болон Миний уур хилэн буудгийг хар. Энэ бол Миний зөвт байдал юм. Би Өөрийн илчилсэн нууц дээр үндэслэн ажлаа төлөвлөж, төлөвлөгөөгөө удирддаг. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй; үүнийг Миний хүслийн дагуу алхам, алхмаар хийх ёстой. Нууц бол Миний ажил өрнөдөг зам, Миний удирдлагын төлөвлөгөөний үе шатуудыг илтгэдэг тэмдэг юм. Нууц буруу бол зам буруу байдаг тул Миний нууцад хэн ч юу ч нэмж, хасах учиргүй. Би яагаад Өөрийн нууцыг та нарт илчилж байна вэ? Шалтгаан нь юу вэ? Та нарын хэн чинь тодорхой хэлж чадах вэ? Мөн Би нууц бол зам гэж хэлсэн, тэгвэл энэ зам гэдгээр юуг хэлж байна вэ? Энэ нь та нарын махан биеэс бие рүү туулдаг үйл явц бөгөөд энэ бол чухал үе шат юм. Би Өөрийн нууцыг илчилсний дараа хүмүүсийн үзэл аажмаар арилж, бодол санаа нь аажмаар намждаг. Энэ бол сүнсний ертөнцөд орох үйл явц юм. Тиймээс Миний ажил үе шаттайгаар явагддаг гэж Би хэлдэг бөгөөд энэ нь тодорхойгүй зүйл биш; энэ бол бодит байдал, мөн Миний ажилладаг арга юм. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, мөн өөр хэн ч үүнийг хийж чадахгүй, учир нь Би бол цор ганц Бурхан Өөрөө билээ! Би Өөрийн ажлыг биечлэн гүйцэлдүүлдэг. Бүхий л орчлон ертөнцийг Би ганцаар хянаж, ганцаар зохицуулдаг. Хэн Намайг сонсохгүй

байж зүрхлэх вэ? (“Би ганцаар” гэдгээр Бурхан Өөрөө гэдгийг хэлж байна, яагаад гэвэл, хүн Би бол Бурхан Өөрөө, тиймээс өөрсдийн үзэлтэй ягштал битгий зууралд.) Хэн Миний эсрэг явж зүрхлэх вэ? Тэд хатуу шийтгүүлнэ! Та нар агуу улаан лууны үр дүнг харсан! Энэ бол түүний төгсгөл бөгөөд энэ бас зайлшгүй тохионо. Ажлыг Би Өөрөө хийх ёстой, тэгснээр тэр шившиг болж, дахин хэзээ ч өндийж чадахгүй, үүрд мөнх устгагдана! Одоо Би нууцыг илчилж эхэлж байна. (Санаж яв! Илчлэгдсэн нууцын ихэнх нь та нарын аман дээрээ хэлдэг боловч хэний чинь ч ойлгодоггүй зүйлс юм.) Хүмүүсийн дуусаагүй гэж хардаг бүх зүйл Миний нүдээр аль хэдийн дууссан байдаг, мөн Миний дөнгөж эхэлж байна гэж хардаг зүйлс хүмүүст бол аль хэдийн дуусчихсан мэт санагддаг гэж Би хэлж байсан. Энэ зөрчилдөөнтэй байна уу? Үгүй. Хүмүүс өөрийн гэсэн үзэл, бодолтой байдаг учир тэгж боддог. Миний төлөвлөдөг зүйлс Миний үгээр дамжин гүйцэлддэг (Намайг хэлэхэд тэдгээр нь байгуулагдаж, Намайг хэлэхэд тэдгээр нь гүйцэлддэг). Гэвч Миний хэлсэн зүйлс гүйцэлдсэн мэт Надад санагддаггүй. Учир нь, Миний хийдэг зүйл цаг хугацааны хязгаартай. Тиймээс Би эдгээр зүйлийг гүйцэд биш гэж хардаг ч, хүмүүсийн махан биеийн нүдэнд (цаг хугацааны ойлголт нь зөрүүтэй байдаг болохоор) аль хэдийн гүйцэлдсэн мэт харагддаг. Өнөө үед ихэнх хүн Намайг илчилсэн нууцаас минь болж сэрдэж байна. Бодит байдал эхэлсэн болохоор, мөн Миний санаа зорилго хүмүүсийн үзэлтэй таардаггүй учир тэд Намайг эсэргүүцэн, үгүйсгэдэг. Энэ бол Сатан өөрөө өөрийнхөө явуулгад урхидуулж байгаа хэрэг юм. (Тэд ерөөл хүлээн авахыг хүсдэг ч Бурхан өөрсдийнх нь үзлээс ийм гажуу байна гэж бодоогүй учир ухарч буцдаг.) Энэ нь мөн Миний ажлын нөлөө юм. Бүх хүн Намайг магтаж, Намайг уухайлж, Надад алдрыг өгөх хэрэгтэй. Маргаангүй бүх зүйл Миний гарт, мөн Миний шүүлт дотор байдаг. Бүх хүн Миний уул руу цувж, ууган хөвгүүд ялгууснаар эргэн ирэх үе нь Миний удирдлагын төлөвлөгөөний эцсийн цэг байх болно. Энэ нь Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө дуусах цаг байх юм. Бүгдийг Би биечлэн зохицуулдаг. Би үүнийг аль хэдийн олон удаа хэлсэн. Та нар одоо ч үзэл дотроо амьдардаг учраас энд та нарыг алдаа гаргаж, Миний төлөвлөгөөг бүү сүйтгээсэй гэсэндээ Би үүнийг удаа дараа онцолдог. Хүмүүс Надад тусалж чадахгүй, бас Миний удирдлагад оролцож ч чадахгүй, учир нь та нар одоо ч мах, цусных (та нар Надад харьяалагддаг ч, махан биед амьдарсаар л байгаа). Тиймээс мах цусны хүмүүс Миний өвийг хүлээн авч чадахгүй гэж Би хэлдэг. Энэ нь мөн та нарыг сүнсний ертөнцөд оруулах үндсэн шалтгаан юм.

Дэлхий дээр, газар хөдлөлт бол гамшгийн эхлэл. Эхлээд Би дэлхий ертөнц буюу газрыг өөрчилнө. Дараа нь тахал, өлсгөлөн ирнэ. Энэ бол Миний төлөвлөгөө, эдгээр нь Миний алхмууд бөгөөд Би Өөртөө үйлчлүүлж, Өөрийн удирдлагын төлөвлөгөөг гүйцэлдүүлэхээр бүх зүйлийг дайчилна. Иймээс орчлон ертөнц Намайг шууд оролцоогүй байсан ч устгагдах болно. Би анх махбод болж, загалмайд цовдлогдоход газар аймшигтайгаар чичирхийлсэн; төгсгөл ирэхэд бас л тийм юм болно. Намайг махбодоос сүнсний ертөнцөд орох яг тэр мөчид газар

хөдлөлт эхэлнэ. Иймээс ууган хөвгүүд гамшгийн зовлонг хэрхэвч амсахгүй, харин ууган хөвгүүдээс бусад нь гамшиг дунд зовохоор үлдэнэ. Тиймээс хүний өнцгөөс бол хүн бүр ууган хөвгүүн байхыг хүсэж байгаа. Хүмүүсийн совингоор бол энэ нь ерөөл эдлэхийн төлөө бус, харин гамшигт зовохоос зайлсхийхийн төлөө юм. Энэ бол агуу улаан лууны явуулга. Гэвч Би түүнийг хэзээ ч зугтаалгахгүй. Би түүнд хатуу шийтгэлээ амсуулан зовоосныхоо дараа босгож, Өөртөө үйлчлүүлнэ (энэ нь Миний хөвгүүд, Миний ардуудыг бүрэн төгс болгохыг хэлж байна), тийнхүү түүнийг өөрийнхөө явуулгад үүрд хууртаж, Миний шүүлтийг үүрд хүлээн авч, үүрд Надаар шатаалгуулахад хүргэнэ. Энэ бол үйлчлэл үзүүлэгчдээр Өөрийгөө магтуулна (Өөрийн агуу хүчийг илчлэхэд тэднийг ашиглан) гэдгийн жинхэнэ утга учир юм. Би агуу улаан лууг Миний хаанчлалд шургалахыг зөвшөөрөхгүй, Би агуу улаан луунд Өөрийг минь магтах эрх олгохгүй! (Учир нь тэгэх нь зохисгүй, хэзээ ч зохистой байхгүй!) Би зөвхөн түүнийг Өөртөө мөнхөд үйлчлүүлнэ! Би зөвхөн түүнийг Өөрийнхөө өмнө нүүрээр нь газар унаган мөргүүлнэ. (Устгагдсан хүмүүс нь мөхөлд орсон хүмүүсээс хавьгүй дээр юм. Сүйрэл бол ердөө түр зуурын хүнд шийтгэл, харин мөхөлд орсон хүмүүс үүрд хатуу шийтгэл туулдаг. Тийм учраас Би, “нүүрээрээ газар унан мөргөх” гэсэн үгийг ашигладаг. Энэ хүмүүс Миний гэрт шургалж, Миний нигүүлслээс нэлээдийг эдэлдэг бөгөөд Миний тухай зарим нэг мэдлэгтэй байдаг учир Би хатуу шийтгэл ашигладаг. Харин Миний гэрийн гаднах хүмүүсийн хувьд гэвэл, мэдлэггүй хүн зовохгүй гэж хэлж болно.) Хүмүүсийн үзлээр бол устгагдах нь мөхөхөөс дор боловч эсрэгээрээ мөхсөн хүмүүс үүрд хатуу шийтгүүлж, устгагдсан хүмүүс үүрд оргүй хоосон руу буцдаг.

109-Р БҮЛЭГ

Өдөр бүр Би айлдвар айлдаж, үг хэлж, агуу тэмдэг, гайхамшгуудаа илчилж байна. Энэ бүх зүйл Миний Сүнсний ажилд багтдаг. Хүмүүсийн нүдэнд Би ердөө л нэг хүн, харин яг энэ хүнд л Би Өөрийнхөө бүх юмыг болон Өөрийн агуу хүчийг илчилдэг.

Хүмүүс хүн Намайг болон Миний үйлдлүүдийг үл тоомсорлодог учраас тэдгээрийг хүний хийсэн зүйл гэж боддог. Тэгвэл, Миний хийдэг зүйлийг хүн хийж чадах эсэх талаар чи яагаад бодож үздэггүй юм бэ? Хүмүүс Намайг энэ хэмжээнд мэддэггүй; тэд Миний үгийг ойлгодоггүй, Миний үйл хэргийг ч ухамсарладаггүй. Ёрын муу, ялзарсан хүмүүс! Хэзээ Би чамайг залгих вэ? Хэзээ Би чамайг гал болон хүхэрт нуурт булах вэ? Маш олон удаа та нар Намайг бүлгээсээ хөөсөн, маш олон удаа хүмүүс намайг доромжилж, элэглэж, гүтгэсэн, маш олон удаа хүмүүс Намайг илт шүүж, эсэргүүцсэн. Сохор хүмүүс! Та нар Миний гарт байдаг атга шавар гэдгээ мэддэггүй гэж үү? Та нар Миний бүтээсэн зүйл гэдгээ мэддэггүй гэж үү? Одоо Миний уур хилэн гарч байгаа, хэн ч үүний эсрэг хамгаалж чадахгүй. Хүмүүс ахин

дахин өршөөл эрж л чадна. Харин Миний ажил энэ хэмжээнд хүртлээ ахисан учир хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Бүтээгдсэн хүмүүс буцаад шавар шороо руугаа буцах ёстой. Би зөвт бус байгаа юм биш, харин та нар дэндүү их завхарсан, цадиггүй байгаа юм, учир нь Сатан та нарыг олзолж, хэрэгслээ болгосон. Би бол ариун Бурхан Өөрөө; Намайг бохирдуулж болохгүй, Би бохир сүмийг эзэмшиж ч чадахгүй. Одоогоос эхлээд, Миний дүрэлзсэн догшрол (уур хилэнгээс ч илүү ширүүн) бүх улс үндэстэн, хүмүүс дээр асгарч, Надаас гарсан мөртөө Намайг мэддэггүй бүх өөдгүй хүмүүсийг гэсгээж эхэлнэ. Би хүмүүсийг туйлын их үзэн яддаг, Надад цаашид өршөөл байхгүй байх болно; харин Өөрийн бүх хараалыг доош асгана. Ямар ч нинжин сэтгэл, хайр байхгүй, бүх зүйл үнсэн товрог болтлоо шатаж, Миний хаанчлал л үлдэнэ, ингэснээр Миний гэрт Миний ардууд Намайг магтаж, Надад алдрыг өгч, Намайг үүрд уухайлан дэмжинэ (энэ бол Миний ардуудын чиг үүрэг юм). Миний гэрийн дотор болон гадна талд байгаа хүмүүсийг Миний гар албан ёсоор гэсгээж эхэлнэ. Нэг ч мууг үйлдэгч Миний гар болон шүүлтээс зугтаж чадахгүй; хүн бүр энэ зовлон зүдүүрийг туулж, Надад шүтэн мөргөх ёстой. Энэ бол Миний сүр жавхлан, түүнчлэн мууг үйлдэгчдэд тунхагладаг захиргааны зарлиг. Хэн ч хэнийг ч аварч чадахгүй. Хүмүүс өөрсдийгөө л халамжилж чадах боловч юу ч хийсэн бай, Миний гэсгээлтийн гараас зугтаж чадахгүй. Миний захиргааны зарлиг хатуу ширүүн гэж хэлсний шалтгаан энд илчлэгддэг; энэ бол бүх хүний нүдээрээ харж болох бодит баримт юм.

Намайг уурлаж эхлэхэд Миний гар өөрсдийг нь үхтэл цохих вий гэдгээс ихэд айсандаа том жижиггүй бүх чөтгөр санд мэнд зугтана—гэхдээ хэн ч Миний гараас зугтаж чадахгүй. Би шийтгэлийн бүх хэрэгслийг гартаа барьдаг; Миний гар бүх зүйлийг хянаж, бүх зүйл Миний гарт байдаг, хэн ч үүнээс мултарч чадахгүй. Энэ бол Миний мэргэн ухаан. Би хүний ертөнцөд ирэхдээ бүх төрлийн бэлтгэл ажлыг аль хэдийн гүйцэлдүүлж, Өөрийн ажлыг хүмүүсийн дунд эхлүүлэх суурийг тавьсан (учир нь Би бол ухаалаг Бурхан бөгөөд юу хийх ёстой, юу хийх ёсгүйг зохих ёсоор шийдвэрлэдэг). Бүх зүйл зохих ёсоор зохицуулагдсаны дараа Би махбод болж, хүний ертөнцөд ирсэн. Гэвч хэн ч Намайг таниагүй. Миний гэгээрүүлсэн хүмүүсээс бусад тэрслүү хөвгүүд бүгд Намайг эсэргүүцэж, Намайг гутааж, Намайг үл тоомсорлодог. Гэхдээ эцэст нь Би тэднийг хүмүүжилтэй, дуулгавартай болгоно. Хэдийгээр хүмүүст Би төдийлөн ихийг хийхгүй байгаа мэт харагдавч Миний агуу ажил аль хэдийн дуусчихсан. (Хүмүүс хүн Намайг үгээрээ, зүрх сэтгэлээрээ аль алинаар нь бүрэн дуулгавартай дагадаг; энэ бол тэмдэг.) Өнөөдөр Би өндийн босож, Намайг эсэргүүцдэг бүх төрлийн муу ёрын сүнсийг гэсгээдэг. Намайг хэр удаан дагаснаас үл хамааран, тэд Миний дэргэдээс явах ёстой. Миний эсрэг байдаг хэнийг ч Би хүсдэггүй (тэд бол сүнслэг ойлголтгүй хүмүүс, муу ёрын сүнсэнд түр зуур эзэмдүүлсэн хүмүүс, мөн Намайг мэддэггүй хүмүүс юм). Би тэдний нэгийг нь ч хүсдэггүй! Бүгд үгүй болж, мөхлийн хөвгүүд болно! Өнөөдөр Надад үйлчлэл үзүүлснийхээ дараа тэд бүгд явах ёстой! Миний гэрт бүү сэлгүүц; ичгүүр

сонжуургүйгээр бусдын хүчийг байнга сорон мөлжихөө боль! Сатанд харьяалагддаг хүмүүс бүгд диаволын хөвгүүд бөгөөд үүрд мөхнө. Намайг эсэргүүцдэг бүхэн Миний дэргэдээс чимээгүй явна, ингэснээр Миний ажлын хурд ямар нэгэн саад болох зүйлгүйгээр илүү төвөггүй болно. Аливаа саад, тотгоргүйгээр бүх зүйл Миний тушаалаар хийгдэнэ. Бүгд Миний харцны өмнө унаж, Миний шатаалтад устгагдана. Энэ нь Миний төгс хүчин, төгс мэргэн ухааныг (ууган хөвгүүддээ Миний хийсэн зүйлийг) харуулдаг. Энэ нь Миний нэрд болон Надад улам их алдрыг нэмнэ. Миний юу хийдгээс болон Миний дууны өнгөнөөс, Өөрийн гэр дэх бүх ажлаа гүйцэлдүүлж, Харь үндэстнүүд рүү хандаж эхэлснийг минь та нар бүгд харж болно. Би Өөрийн ажлыг тэнд эхлүүлж, ажлынхаа дараагийн алхмыг гүйцэтгэж байгаа.

Миний ихэнх үг та нарын үзэлтэй нийцдэггүй—гэхдээ битгий яв, Миний хөвгүүд ээ. Хүний үзэлтэй нийцэхгүй байна гэдэг нь Миний айлдвар биш гэсэн үг биш. Би тэдгээрийг үнэхээр айлдсан гэдгийг яг энэ нь л нотолдог. Хэрвээ Миний үг хүний үзэлтэй нийцдэг байсан бол тэр нь муу ёрын сүнсний ажил байх байсан. Тиймээс та нар Миний үгэнд илүү их хүчин чармайлт гаргаж, Миний хийдгийг хийж, хайрладгийг хайрлах ёстой. Энэ эцсийн эрин үе нь бас бүх гай гамшиг дахин гарч ирэх эрин үе бөгөөд түүнчлэн Би Өөрийн бүх зан чанарыг илчилж буй эрин үе билээ. Миний бүх ариун бүрээ үлээж эхлэхэд хүмүүс үнэхээр айх болно; тэр үед хэн ч ёрын муу зүйл хийж зүрхлэхгүй, харин Миний өмнө нүүрээрээ газар унан мөргөж, Миний мэргэн ухаан, төгс хүчинд талархана. Эцсийн эцэст Би бол ухаалаг Бурхан Өөрөө! Хэн Намайг няцааж чадах вэ? Бас хэн Миний эсрэг өндийн босож зүрхлэх вэ? Хэн Миний мэргэн ухааныг хүлээн зөвшөөрөхгүй байж зүрхлэх вэ? Хэн Миний төгс хүчнийг мэдэхгүй байж зүрхлэх вэ? Миний Сүнс бүх газарт агуу ажил хийж байх үед хүн бүр Миний төгс хүчнийг мэддэг ч Миний зорилго биелээгүй л байна. Миний уур хилэнгээс үүдэн хүмүүс Миний төгс хүчин, мэргэн ухаан, мөн Миний үнэн биеийн алдар сууг хараасай гэж Би хүсдэг. (Энэ бүхэн ууган хөвгүүдээс харагддаг; энэ бол туйлын үнэн. Тэднээс өөр хэн ч Миний үнэн биеийн нэг хэсэг байж чадахгүй; үүнийг Би урьдчилан тодорхойлсон.) Миний гэрт, хүмүүсийн ухан ойлгож чадахгүй эцэс төгсгөлгүй нууц бий. Намайг ярихад хүмүүс Намайг хэтэрхий өршөөлгүй гэдэг. Мөн аль хэдийн маш олон хүн Намайг тодорхой түвшинд хайрладаг гэж хэлдэг. Тэгвэл Би яагаад тэднийг агуу улаан лууны үр сад гэдэг юм бэ? Түүнчлэн яагаад Би тэднийг нэг нэгээр нь орхих вэ? Миний гэрт илүү олон хүн байвал сайн биш гэж үү? Гэсэн ч Би ийм маягаар үйлдсээр л байдаг. Миний урьдчилан тогтоосон тооноос нэгээр илүү, эсвэл нэгээр дутуу байж болохгүй. (Энэ бол Миний захиргааны зарлиг. Үүнийг ямар ч хүн өөрчилж чадахгүйгээр зогсохгүй, Би Өөрөө ч үүнийг өөрчилж чадахгүй, учир нь Би Сатаны өмнө буулт хийх ёсгүй. Миний мэргэн ухаан, Миний сүр жавхланг үзүүлэхэд энэ хангалттай. Би бол цорын ганц Бурхан Өөрөө. Хүмүүс Миний өмнө сөгддөг; Би хүмүүсийн өмнө буулт хийдэггүй.) Сатаныг хамгийн их шившиглэдэг зүйл бол яг энэ юм. Миний сонгосон хүмүүс бүгд даруу, хүлцэнгүй, дуулгавартай, үнэнч шударга бөгөөд Надад төлөв

даруу байдлаар, анзаарагдалгүйгээр үйлчилж чадна. (Сатан Намайг шившиглэхдээ үүнийг ашиглахыг хүссэн ч Би Сатантай хариу барьсан.) Миний зан чанарыг энэ хүмүүсээс харж болно. Тулаанд ялалт байгуулаад эргэж ирэх үедээ Би ууган хөвгүүдээ Өөрийн хаанчлалын хаад болгон тослох бөгөөд тэр үед л Би амарч эхэлнэ, учир нь Миний ууган хөвгүүд Надтай хамт хаанчилна. Миний ууган хөвгүүд Намайг төлөөлдөг, Намайг илэрхийлдэг. Даруу агаад олонд танигдаагүй үйлчлэлээрээ тэд Надад дуулгавартай байдаг; үнэнч шударга байдлаараа Миний үгийг гүйцэтгэдэг; үнэнч шударга байдлаараа тэд Миний хэлдэг зүйлийг хэлдэг; даруу байдлаараа Миний нэрд алдар суу авчирдаг (эрээ цээргүй зан, эсвэл зэрлэг бүдүүлэг байдалгүйгээр, харин ч сүр жавхлан болон уур хилэнтэйгээр). Миний ууган хөвгүүд ээ! Орчлон ертөнцийг шүүх цаг боллоо! Би та нарт адис хайрлаж, эрх мэдэл өгдөг, мөн Би та нарыг ерөөлийн нэг хувиар шагнадаг! Бүх зүйл аль хэдийн гүйцэлдсэн, үүнийг бүгдийг нь та нар хянаж, та нар зохицуулна, учир нь Би та нарын Эцэг; Би та нарын хүчит цамхаг, Би та нарын орогнох газар, Би та нарын дэмжлэг. Түүнчлэн Би та нарын Төгс Хүчит Нэгэн; Би та нарын бүх зүйл билээ! Бүх зүйл Миний гарт байдаг, бүх зүйл бас та нарын гарт ч байна. Үүнд зөвхөн өнөөдөр ч биш, өчигдөр ч, бүр маргааш ч гэсэн багтдаг! Үүнийг тэмдэглүүштэй биш гэж үү? Уухайлан баярлууштай биш гэж үү? Та нар бүгд өөрсдийн хүртэх ёстой хувийг Надаас хүлээн авцгаа! Би Өөртөө ганцыг нь ч хадгалалгүйгээр та нарт бүх юмаа өгдөг, учир нь Миний бүх өмч хөрөнгө та нарынх, мөн Миний баялаг та нарынх. Энэ бол та нарыг бүтээснийхээ дараа “маш сайн” гэж хэлсний минь шалтгаан билээ.

Өнөөдөр юу хэлж, бодож, хийхийг чинь хэн чиглүүлдгийг та нар мэдэх үү? Та нарын үйлдлийн цаад зорилго юу вэ? Би та нараас асууя: Та нар Хурганы хуримын зоогт хэрхэн оролцох вэ? Энэ нь өнөөдөр үү? Эсвэл ирээдүйд үү? Хурганы хуримын зоог гэж юу вэ? Та нар мэдэхгүй, тийм үү? Тэгвэл Би та нарт тайлбарлаж өгье: Би хүний ертөнцөд ирэхдээ, өнөөдрийн хүн Өөртөө үйлчлүүлэхээр бүх төрлийн хүн, юмс, зүйлсийг зохицуулсан. Одоо бүх зүйл гүйцэлдсэн болохоор Би үйлчлэл үзүүлэгчдийг хаяж байна. Энэ нь хуримын зоогтой ямар хамаатай юм бэ? Энэ хүмүүс Надад үйлчлэл үзүүлэх үед буюу Би Хурга болох үедээ хуримын зоогийн амтыг мэдэрдэг. Өөрөөр хэлбэл, Миний туулсан бүх шаналал, Миний хийсэн, хэлсэн бүх зүйл, Миний уулзсан бүх хүн, насан туршдаа Миний хийсэн бүх зүйл хуримын зоогт багтсан. Хүн Намайг тослуулсны дараа та нар Намайг дагаж эхэлсэн (энэ үед Би Хурга болсон); тиймээс Миний удирдлага дор та нар төрөл бүрийн шаналал, гамшиг туулж, дэлхий ертөнцөд хаягдаж, дорд үзэгдэж, гэр бүлдээ хаягдаж, Миний ерөөл дор амьдарсаар ирсэн. Энэ бүх зүйл бол Хурганы хуримын зоогийн хэсгүүд юм. Би “хуримын зоогийг” хэрэглэдэг, учир нь та нараар хийлгэж байгаа бүхэн минь та нарыг олж авах зорилготой байдаг. Гэхдээ энэ нь бүгд зоогийн нэг хэсэг билээ. Ирээдүйд, эсвэл өнөөдөр та нарын эдэлдэг, олж авдаг бүх зүйл, мөн Надтай хуваалцдаг хааны эрх мэдэл бүгд зоогийн нэг хэсэг юм гэж хэлж болно. Миний хайр Намайг хайрладаг бүх хүнд очдог. Миний хайрладаг

хүмүүс үүрд үлдэж, хэзээ ч үгүй болохгүй бөгөөд үүрд Миний хайран дотор байх болно. Энэ бол үүрдийнх!

110-Р БҮЛЭГ

Бүх зүйл илчлэгдэх тэр үе бол Би амрах цаг, түүнчлэн, бүх зүйл эмх цэгцэд орох үе байх болно. Би Өөрийн ажлыг биечлэн хийдэг; бүх зүйлийг Би Өөрөө зохион байгуулж, зохицуулдаг. Сионоос гарч ирэх болон буцах үедээ, мөн ууган хөвгүүдээ бүрэн төгс болгох үедээ Би Өөрийн агуу ажлыг дуусгасан байх болно. Хүмүүсийн үзлээр бол, хийгдсэн зүйлийг харж, мэдрэхүйц байх ёстой, харин Миний харж байгаагаар, Намайг үүнийг төлөвлөх мөчид бүх зүйл гүйцэлддэг. Сион бол Миний гэр орон, бас Миний хүрэх газар билээ; Би тэнд Өөрийн төгс хүчийг илчилж, Би Өөрийн ууган хөвгүүдийн хамтаар гэр бүлээрээ аз жаргалаа хуваалцана. Тэнд Би тэдэнтэй хамт үүрдийн үүрд амьдарна. Сион, хүмүүсийн хүсэн тэмүүлдэг тэр үзэсгэлэнт газар. Эрин үеүдийн туршид тоо томшгүй олон хүн Сион руу тэмүүлж ирсэн боловч анхнаасаа ганц ч хүн ороогүй. (Өнгөрсөн үеүдийн ариун хүмүүс болон эш үзүүлэгчдийн аль нь ч тэр Сион руу ороогүй; учир нь, Би ууган хөвгүүдээ эцсийн өдрүүдэд сонгож байгаа ба тэд бүгд энэ цаг үед төрж байгаа; үүгээр дамжуулан Миний ярьсан өршөөл, нигүүлсэл минь илүү ил тод болдог.) Одоо ууган хөвгүүд болсон хүн бүр Надтай хамт Сион руу орж, тэрхүү ерөөлийг эдлэх болно. Би Өөрийн ууган хөвгүүдийг тодорхой түвшинд өргөж байгаа, учир нь тэдэнд Миний хэв чанар, Миний суу алдарт дүр төрх байдаг бөгөөд тэд Надад гэрчлэл хийж, Намайг алдаршуулж, Намайг амьдран харуулж чадна. Түүнчлэн, тэд Сатаныг дийлж, агуу улаан лууг шившиглэх чадвартай. Яагаад гэвэл Миний ууган хөвгүүд ариун онгон; тэд бол Миний хайрладаг, Миний сонгож, таалсан хүмүүс билээ. Би тэднийг өргөдгийн шалтгаан нь тэд өөрсдийн байр сууринд зогсож, даруухнаар нууцхан Надад үйлчилж, Надад хүчирхэг гэрчлэл хийж чадна. Би Өөрийн бүх эрч хүчийг ууган хөвгүүдийнхээ төлөө зарлагадаж, тэдэнд үйлчлүүлэхээр бүх төрлийн хүн, үйл явдал, юмсыг хянамгай зохицуулсан. Эцэст нь, Би Өөрийн бүрэн алдрыг ууган хөвгүүдээр дамжуулан бүх хүнд харуулж, тэдний ачаар бүх хүнийг Өөртөө бүрэн үнэмшүүлэх болно. Би ямар ч чөтгөрийг хүчлэхгүй, Надад гэрчлэл байгаа, мөн Миний гарт эрх мэдэл байгаа учир тэднийг эрээгүй аашлахаас, эсвэл тэдний балмад байдлаас Би айдаггүй. Сатаны төрлийн хүмүүс ээ, Намайг одоо сонс! Миний айлддаг үг бүр, Миний хийдэг юм бүхний цаад зорилго нь ууган хөвгүүдээ төгс болгох явдал юм. Тиймээс чи Миний тушаалыг анхаарч, Миний ууган хөвгүүдийг дуулгавартай дагах ёстой; эс бөгөөс Би чамтай харьцаж, тэр даруй мөхөөх болно! Миний ууган хөвгүүд Миний захиргааны зарлигийг хэдийнээ хэрэгжүүлж эхэлсэн, учир нь зөвхөн тэд л Миний сэнтийг хамгаалах эрхтэй; Би тэднийг хэдийнээ тосолсон. Миний ууган хөвгүүдэд захирагддаггүй хэн боловч мэдээжийн хэрэг олигтой биш, агуу улаан луу Миний удирдлагын төлөвлөгөөг нураах

гэж тэднийг илгээсэн нь дамжиггүй. Ийм олиггүй этгээдийг Миний гэрээс тэр дор нь хөөн гаргах ёстой. Тиймэрхүү юм Надад үйлчлэл хийхийг Би хүсэхгүй; тэр үүрдийн сүйрэлтэй нүүр тулах болно—тун удахгүй, саадгүй нүүр тулна! Надад үйлчилдэг хүмүүс Миний сайшаалыг хэдийнээ хүртсэн байх ёстой; тэд төлөх ёстой байж болзошгүй төлөөсөндөө санаа зоволгүйгээр дуулгавартай байх ёстой. Хэрвээ тэд тэрслүү бол Надад үйлчлэл үзүүлэхэд тэнцэхгүй; Надад иймэрхүү амьтан хэрэггүй. Тэд хурдан эндээс зайлах ёстой; Би тэднийг огт хүсдэггүй! Та нар одоо үүнийг тодорхой ойлгосон байх ёстой! Надад үйлчлэл үзүүлдэг хүмүүс үүнийг сайн хийж, асуудал гаргах ёсгүй. Хэрвээ чамд ямар ч найдваргүй мэт санагдан, асуудал гаргаж эхэлбэл, Би чамайг түдгэлзэлгүйгээр дуусгах болно! Надад үйлчилдэг чи үүнийг тодорхой ойлгож байна уу? Энэ бол Миний захиргааны зарлиг.

Надад гэрчлэл хийх нь Миний ууган хөвгүүдийн үүрэг, иймээс Би та нараас Миний төлөө ямар нэгэн зүйл хийхийг шаарддаггүй; та нар үүргээ зохих ёсоор гүйцэтгэж, Миний та нарт хайрласан ерөөлийг эдэлж л байвал Би сэтгэл хангалуун байх болно. Би бүхий л орчлон ертөнц даяар, газар дэлхийн зах хязгаар хүртэл аялахдаа ууган хөвгүүдээ сонгож, бүрэн төгс болгосон. Энэ бол дэлхийг бүтээхээс өмнө Миний хийж дуусгасан зүйл; хүн төрөлхтний дундаас хэн ч үүнийг мэдэхгүй, гэхдээ Миний ажил чимээгүйхэн хийгдсэн. Энэхүү баримт нь хүний үзэлтэй нийцдэггүй! Гэхдээ баримт бол баримт, хэн ч тэдгээрийг өөрчилж чадахгүй. Том, жижиг бүх чөтгөр хуурамч дүрээрээ жинхэнэ төрхөө илчилж, янз бүрийн хэмжээгээр Миний гэсгээлтэд өртөнө. Миний ажилд алхам, Миний үгэнд мэргэн ухаан байдаг. Миний үг, үйлдлээс та нар ямар нэгэн зүйл харсан уу? Би зүгээр нэг юм хийгээд, хэлээд байна уу? Миний үг ердөө л ширүүн, шүүмжилсэн, эсвэл тайвшруулсан байна уу? Тэр нь хэтэрхий энгийн ч гэсэн хүн төрөлхтний хувьд үүнийг харах нь огтхон ч энгийн биш. Миний үгэнд мэргэн ухаан, шүүлт, зөвт байдал, сүр жавхлан, тайтгарал байгаад зогсохгүй, үүнээс ч илүүтэйгээр Надад юу байгаа, Би юу болохыг агуулдаг. Миний үг нэг бүр хүн төрөлхтний илчилж чадахгүй нууц юм; Миний үг туйлын ойлгошгүй бөгөөд хэдийгээр нууцууд илчлэгдсэн ч, хүн төрөлхтний чадварт тулгуурлавал, тэдгээр нь хүн төрөлхтний төсөөлөл, ойлголтын хүрээний гадна байсаар байна. Миний хувьд ойлгоход хамгийн энгийн үг нь хүмүүст ойлгоход хамгийн хэцүү зүйл байдаг, иймд хүн бид хоёрын ялгаа нь тэнгэр, газрын хоорондох ялгаа шиг юм. Ийм учраас, Би Өөрийн ууган хөвгүүдийн хэлбэрийг бүхэлд нь өөрчилж, тэднийг бүхэлд нь бие рүү оруулахыг хүсдэг. Ирээдүйд, тэд махан биеэс бие рүү ороод зогсохгүй дотор нь байхдаа хэлбэрээ янз бүрийн хэмжээнд өөрчлөх болно. Энэ бол Миний төлөвлөгөө. Энэ бол хүмүүсийн хийж чадахгүй зүйл; тэдэнд үүнийг хийх ямар ч арга зам үгүй. Иймд, Би үүнийг та нарт нарийвчлан тайлбарлалаа ч гэсэн та нар үүнийг ойлгохгүй л байх болно; та нар зөвхөн ер бусын мэдрэмжид л орж чадна. Учир нь Би бол ухаалаг Бурхан Өөрөө билээ.

Та нар нууцуудыг харахаараа бүгд зарим нэг байдлаар хариу үйлдэл үзүүлдэг. Хэдийгээр та нар зүрх сэтгэлийнхээ гүнд эдгээр нууцыг хүлээн авч, хүлээн

зөвшөөрдөггүй ч, амаараа хүлээн зөвшөөрдөг. Иймэрхүү хүмүүс хамгийн ов мэхтэй бөгөөд Би нууцуудыг илчлэхдээ тэднийг нэг нэгээр нь таягдаж, хаях болно. Гэхдээ Би бүх зүйлийг алхмуудаар хийдэг. Би аливааг яаран хийдэггүй, бас сохроор дүгнэлтэд хүрдэггүй; учир нь Надад бурханлаг зан чанар байдаг. Би одоо юу хийж байгаа, дараагийн алхамдаа юу хийхийг минь хүмүүс тодорхой харж огт чаддаггүй. Би нэг алхмын үгийг хэлэх үед л Миний ажилладаг арга зам Надтай хамт нэг алхам урагшилдаг. Бүх зүйл Миний үгэн дотор тохиолдож, бүх зүйл Миний үгэн дотор илчлэгддэг учраас хэн ч тэвчээргүй байх ёсгүй; Надад зүй ёсоор үйлчлэл үзүүлэх л хангалттай. Эрин үеүдийн өмнө Би инжрийн модны талаар зөгнөсөн, гэтэл эрин үеүдийн турш хэн ч инжрийн модыг хараагүй, хэн ч үүнийг тайлбарлаж чадаагүй, хэдийгээр урьдын магтаалуудад энэ хэллэг дурдагдсан ч гэсэн хэн ч үүний жинхэнэ утгыг мэдээгүй. Эдгээр үг нь “агуу гамшиг” гэх хэллэг шиг хүмүүсийг будилуулсан бөгөөд энэ нь хүн төрөлхтөнд хэзээ ч задлаагүй нууц байсан билээ. Инжрийн мод бол нэг төрлийн сайн жимсний мод байх, цаашилбал энэ нь ариун хүмүүсийг хэлдэг гэж хүмүүс бодсон хэдий ч эдгээр үгийн жинхэнэ утгаас нь маш хол байсаар л байсан. Би эцсийн өдрүүдэд Өөрийн хуйлмал номыг дэлгэхдээ та нарт үүнийг хэлнэ. (“Хуйлмал ном” гэдэг нь Миний хэлсэн бүх үг—эцсийн өдрүүд дэх Миний үгийг хэлдэг; энэхүү ном нь тэр бүгдийг агуулдаг.) Инжрийн мод гэдэг нь Миний захиргааны зарлиг—нэг бүрийг нь хэлдэг. Гэхдээ энэ бол үүний ямар утгатай болохын ердөө нэг хэсэг нь юм. Инжрийн модны нахиалах нь Би махбодоор ажиллаж, ярьж эхэлж байгаа боловч Миний захиргааны зарлиг мэдэгдээгүй хэвээр байгааг хэлдэг (учир нь, тэр үед Миний нэрийг хараахан гэрчлээгүй, Миний захиргааны зарлигийг хэн ч мэдээгүй байсан). Миний нэрийг гэрчилж, түгээж, бүх хүн магтаж, Миний захиргааны зарлиг үр дүнд хүрэх үед инжрийн мод үр шимээ өгнө. Энэ бол юуг ч орхигдуулаагүй, бүрэн дүүрэн тайлбар; энд бүгд илчлэгдсэн (Миний өмнөх үгэнд, Миний бүрэн гүйцэд илчлээгүй хэсэг байсан учраас Би үүнийг хэлж байна; иймээс та нар тэвчээртэй хүлээж, эрж хайх хэрэгтэй байсан).

Би ууган хөвгүүдийг бүрэн төгс болгохдоо, Өөрийн бүрэн алдар, Өөрийн төрх байдлыг бүхэлд нь орчлон ертөнцөд илчилнэ. Үүнийг биеэр хийж, энэ нь бүх хүний дээр Өөрийн үнэн биед байх болно; энэ нь Миний Сион уулан дээр, Миний алдар суунд, тэр тусмаа магтаалын дуун дунд хийгдэнэ. Түүнчлэн, Миний дайснууд Миний эргэн тойронд ухарч, ёроолгүй нүх, хүхэртэй галт нуур луу буух болно. Өнөөдөр хүмүүсийн төсөөлж чадах зүйл хязгаарлагдмал бөгөөд Миний анхдагч санаа зорилготой нийцдэггүй; өдөр бүр үг хэлэх үедээ хүмүүсийн үзэл, бодлыг онилдгийн минь шалтгаан энэ юм. Миний хэлдэг зүйл бүхэлдээ та нарт нийцэж, та нар ямар ч эсэргүүцэл үзүүлэхгүй байх өдөр (бие рүү орох өдөр) ирнэ. Тэр үед та нар өөрийн гэсэн бодолтой байхаа больж, Би айлдвар тавихаа болино. Та нар өөрийн гэсэн бодолтой байхаа болих учир Би та нарыг шууд л гэгээрүүлнэ—энэ бол ууган хөвгүүдийн эдлэх ерөөл бөгөөд тэд Надтай хамт хаан болж хаанчлах үед ийм зүйл болно. Хүмүүс өөрсдийн төсөөлж чадахгүй зүйлд итгэдэггүй, үүнд итгэдэг

зарим нэг хүн байлаа ч, Би тусгайлан гэгээрүүлсэн учраас л тэгдэг. Эс бөгөөс, хэн ч итгэхгүй бөгөөд энэ бол туулах ёстой зүйл юм. (Энэ алхмыг туулахгүйгээр, Миний агуу хүчийг илчилж чадахгүй бөгөөд энэ нь Би Өөрийн айлдвар төдийхнөөр дамжуулан хүмүүсийг үзлээс нь салгадаг гэсэн үг юм. Өөр хэн ч энэ ажлыг хийж чадахгүй, хэн ч Намайг орлож чадахгүй. Би бол үүнийг гүйцэлдүүлж чадах цор ганц Нэгэн; гэхдээ энэ нь туйлын биш. Би хүн төрөлхтнөөр дамжуулж энэ ажлыг хийх ёстой.) Хүмүүс Миний үгийг сонсоод эрч хүч авдаг ч эцэст нь тэд бүгд ухарч няцдаг. Тэд өөрийн эрхгүй ингэдэг. Үүний зэрэгцээ, хүмүүсийн ухаарч чадахгүй нууцууд бий. Хэн ч юу тохиолдохыг төсөөлж чадахгүй, харин Би та нарт, үүнийг Миний илчилдэг зүйлээс харах боломж олгох болно. Үүгээр дамжуулан “Миний хэрэгцээнд тохирохгүй бүх хүнийг Би үндсээр нь устгах болно” хэмээх Миний энэхүү үгийн жинхэнэ утга илэрхий болно. Миний ууган хөвгүүд янз бүрийн илрэлтэй, Миний дайснууд ч мөн адил. Тэднийг бүгдийг нь та нарт нэг нэгээр нь илчлэх болно. Санаж яв! Ууган хөвгүүдээс өөр хэнд ч муу сүнсний ажил байдаг. Тэд нар бүгд Сатаны зарц юм. (Удахгүй тэд нэг нэгээрээ илчлэгдэх боловч эцсийг нь хүртэл үйлчлэл хийх шаардлагатай зарим хүн, хэсэг хугацаанд л үйлчлэл хийх шаардлагатай зарим хүн байдаг.) Миний үгийн ажил дор, бүгд үнэн төрхөө харуулах болно.

Бүх улс үндэстэн, бүх газар, бүх урсгал Миний нэрийн баялгийг эдэлдэг. Гай гамшиг одоогоор хуримтлагдаж, Миний атганд байгаа, мөн Би үүнийг аажмаар буулгахаар бэлдэж байгаа учраас хүн бүр үнэн замыг яаралтай эрж хайж байгаа бөгөөд ингэсний төлөөс нь бүхнээс татгалзах байсан ч гэсэн үүнийг эрж хайх ёстой. Би бүх зүйлд Өөрийн гэсэн цагтай. Би үүнийг гүйцэлдэх болно гэж хэлбэл, яг тэр үед, тэр минут, бүр тэр секундэд гүйцэлдэх болно. Хэн ч үүнд саад болж, үүнийг зогсоож чадахгүй. Эцсийн эцэст, агуу улаан луу бол Миний эрхэндээ оруулсан дайсан; тэр бол Надад үйлчлэл үзүүлэгч бөгөөд Би юу ч хэлсэн бай тэр өчүүхэн ч эсэргүүцэлгүйгээр хийдэг. Тэр бол үнэхээр Миний ачаа болсон араатан юм. Миний ажил гүйцэлдэхэд Би түүнийг ёроолгүй нүхэнд, хүхэртэй галт нууранд хаях болно (Би устгагдах хүмүүсийг хэлж байна). Устгагдах хүмүүс үхлийг амсаад ч зогсохгүй, Намайг хавчиж хяхсаныхаа төлөө хатуу шийтгүүлэх болно. Энэ бол үйлчлэл үзүүлэгчдээр дамжуулан Миний хийсээр байх ажил юм. Би Сатанаар өөрийг нь хөнөөлгөж, устгуулж, агуу улаан лууны үр садыг бүхэлд нь ор мөргүй сөнөөнө. Энэ бол Миний ажлын нэг хэсэг; үүний дараа Би Харь үндэстнүүд рүү хандах болно. Эдгээр нь Миний ажлын алхам билээ.

111-Р БҮЛЭГ

Бүх улс үндэстэн Таны ачаар ерөөгдөх нь гарцаагүй; бүх хүн Таны ачаар Намайг сайшааж, магтана. Миний хаанчлал хөгжин дэвжиж, үүрд оршин тогтнох болно. Үүн дээр гишгэлэхийг хэнд ч зөвшөөрөхгүй ба Надтай нийцдэггүй юуг ч

оршихыг зөвшөөрөхгүй, учир нь Би бол ямар ч зөрчлийг үл хүлцдэг сүр жавхлант Бурхан Өөрөө юм. Намайг шүүхийг Би хэнд ч зөвшөөрдөггүй, Надтай нийцэлгүй байхыг хэнд ч зөвшөөрдөггүй. Миний зан чанар болон сүр жавхлан эндээс хангалттай харагддаг. Хэн нэгэн Намайг эсэргүүцэхэд Би Өөрийнхөө цагт түүнийг шийтгэнэ. Хэн нэгнийг шийтгэхийг минь яагаад хэн ч хараагүй вэ? Учир нь Миний цаг хараахан ирээгүй байна, Миний гар хараахан жинхэнээсээ хөдөлж эхлээгүй байна. Хэдийгээр их гамшиг үй олноороо тохиолдсон ч энэ нь их гамшгууд ямаршуу байхыг харуулсан төдий юм, харин хэнд ч бодит байдал дээр тохиолдоогүй байна. Та нар Миний үгээс ямар нэгэн зүйл ер нь ойлгож авав уу? Өнөөдөр Би их гамшгуудын бодит байдлыг илчилж эхлэх болно. Үүний дараагаар, Намайг эсэргүүцсэн хэн ч байсан Миний гарт цохигдон унана. Өнгөрсөнд, Би хэдхэн хүмүүсийг л илчилсэн; ямар ч их гамшиг хараахан ирээгүй байна. Өнөөдөр бол өнгөрснөөс ондоо. Нэгэнт Би та нарт их гамшгууд ямаршуу байхыг бүгдийг нь хэлсэн учир их гамшгуудын бодит байдлыг товлосон цагт Би олон нийтэд зарлах болно. Үүнээс өмнө хэн ч их гамшигт өртөж байгаагүй, иймд ихэнх хүмүүс (өөрөөр хэлбэл, агуу улаан лууны хөвгүүд) болчимгүй, зоргоороо аашилсаар ирсэн. Бодит байдалтай нүүр тулахад эдгээр жигшүүртэй амьтад бүрэн үнэмших болно. Эс тэгвээс, бүгд Надад итгэлгүй байж, хэн ч Миний талаар тодорхой мэддэг байж чадахгүй. Энэ бол Миний захиргааны зарлиг. Үүнээс Миний ажилладаг арга барил (бүх хүн дээр ажилладаг Миний арга барилыг хэлж байна) өөрчлөгдөж эхэлснийг харж болно: Агуу улаан лууны үр удмаар дамжуулан Би Өөрийн уур хилэн, шүүлт, хараалыг үзүүлж байгаа бөгөөд Намайг эсэргүүцдэг бүгдийг Миний гар гэсгээж эхэлсэн. Ууган хөвгүүдээр дамжуулан Би Өөрийн өршөөл, энэрлийг үзүүлж байна. Түүгээр ч зогсохгүй Би ууган хөвгүүдээр дамжуулан зөрчлийг үл хүлцдэг Өөрийн ариун зан чанар, Өөрийн эрх мэдэл болон Өөрийн үнэн биеийг үзүүлж байна. Үйлчлэл үзүүлэгчид Надад үйлчлэхээр төвхнөж, Миний ууган хөвгүүд улам илүү танигдах болсон. Намайг эсэргүүцдэг хүмүүсийг цохиж унагаснаар Би үйлчлэл үзүүлэгчдэд Өөрийн өршөөлгүй гарыг харуулдаг учраас тэд дагжин чичирсээр Надад үйлчлэл үзүүлдэг. Түүнчлэн Би ууган хөвгүүдийнхээ амийг өсгөх үүднээс тэдэнд Өөрийн эрх мэдлийг харуулж, Өөрийгөө илүү сайн ойлгуулдаг. Эцсийн үед хэлсэн Миний үг (захиргааны зарлиг, зөгнөл болон бүх төрлийн хүмүүсийн шүүлтийг оролцуулаад) дэс дарааллаараа биелж эхэлж байна, өөрөөр хэлбэл, хүмүүс нүднийх нь өмнө Миний үг биелэхийг, Миний нэг ч үг хий хоосон биш бөгөөд бүгд бодитой гэдгийг харна. Миний үгийг биелэхээс өмнө, олон хүн биелэхгүй байхаар нь орхин явна. Энэ бол Миний ажилладаг арга барил—энэ бол дан ганц Миний төмөр таягийн чиг үүрэг биш, үүнээс гадна Миний үгийн мэргэн ухаан юм. Эндээс, хүн Миний бүхнийг чадагч байдлыг болон агуу улаан лууг үзэн ядах сэтгэлийг минь харж болно. (Намайг ажлаа эхэлсний дараа л үүнийг харж болно. Одоо зарим хүн илчлэгдсэн—энэ нь Миний гэсгээлтийн өчүүхэн хэсэг боловч үүнийг их гамшигт тооцож болохгүй. Үүнийг ойлгоход хэцүү биш. Ийм учраас,

одоогоос эхлээд Миний ажилладаг арга барил хүмүүст ойлгоход улам хэцүү байх болно гэдгийг эндээс харж болно. Өнөөдөр Би та нарт ингэж хэлж байгаа нь цаг нь ирэхэд та нарыг үүнээс болж сул дорой байлгахгүй гэсэндээ юм. Энэ бол Миний та нарт даалгаж байгаа зүйл, учир нь хүмүүст эрт цагаас хойш үзэгдэж харагдаагүй зүйлс, хүмүүст сэтгэл хөдлөл болон өөрийгөө зөвтгөдөг байдлаа хойш тавихад нь хүндрэл үүсгэх зүйлс тохионо.) Би агуу улаан лууг шийтгэхдээ өөр өөр арга барил хэрэглэдэг шалтгаан нь тэр бол Миний өстөн, Миний дайсан учраас юм. Би үүний бүх үр удмыг устгах ёстой—тэгсэн цагт л Би Өөрийн зүрх сэтгэлээс үзэн ядалтыг салгаж, агуу улаан лууг зүй ёсоор шившиглэж чадна. Зөвхөн энэ л агуу улаан лууг бүхэлд нь устгаж, хүхэртэй галт нуур, ёроолгүй нүх рүү хаяж байгаа явдал юм.

Би зөвхөн өчигдөр л ууган хөвгүүдээ Өөртэйгөө хамт хаан суулгаж, тэднээр бүх улс үндэстнийг захируулж, ерөөлүүдийг эдлүүлэхээр Өөртэйгөө нэгдүүлж байгаа хэрэг юм биш; Би өнөөдөр ч үүнийг хийдэг, хамгийн гол нь маргааш ч хийх болно. Би Өөрийн ажлыг амжилттай гүйцэлдүүлсэн—Би цаг үргэлж ингэж хэлсээр ирсэн, бүтээлийн цагийн эхлэлээс эхлээд Би ингэж хэлж эхэлсэн гэж хэлсэн ч болно, гэтэл хүмүүс Миний юу хэлж байгааг ойлгодоггүй. Бүтээлийн цагаас эхлээд одоог хүртэл Би биечлэн ажиллаж байгаагүй; өөрөөр хэлбэл, Миний Сүнс үг хэлж, ажиллахаар хэзээ ч хүн дээр бүрэн буугаагүй. Харин өнөөдөр бол өнгөрснөөс ондоо: Миний Сүнс орчлон ертөнцийн хаа сайгүй биечлэн ажиллаж байна. Учир нь эцсийн өдрүүдэд Надтай хамт эрх барьж хаанчлах хэсэг бүлэг хүмүүсийг олж авахыг Би хүсэж байгаа тул эхлээд Надтай нэг санаатай байдаг, Миний ачааг анхаарч үздэг хүнийг олж авдаг. Үүний дараа, дуу хоолойг минь илэрхийлэхийн тулд Миний Сүнс Түүн дээр бүрэн бууж, орчлон ертөнцөд Миний захиргааны зарлигийг гаргаж, нууцуудыг минь илчилнэ. Миний Сүнс Түүнийг биечлэн төгс болгоно; Миний Сүнс Түүнийг биечлэн сахилгажуулна. Тэр хэвийн хүн чанарт амьдардаг учир хэн ч тодорхой харж чадахгүй. Миний ууган хөвгүүд биед орох үед Миний одоо хийдэг зүйл бодит байдал мөн эсэх нь бүхэлдээ тодорхой болно. Мэдээжийн хэрэг, хүний нүдээр, хүний үзлээр бол хэн ч итгэж, хэн ч дуулгавартай байх боломжгүй. Гэхдээ энэ бол хүмүүст гаргадаг Миний хүлээцтэй байдал. Бодит байдал хараахан ирээгүй байгаа учраас хүмүүс итгэж эсвэл ойлгож чаддаггүй. Хүний үзлээрээ Миний үгэнд итгэх хүн нэг ч байгаагүй. Хүмүүс бүгд яг ийм: Нэг бол тэд Миний махбодоор хэлсэнд л итгэдэг, эсвэл Миний Сүнсний дуу хоолойд л итгэдэг. Энэ бол хүмүүсийн хувьд учрыг нь олоход хамгийн хэцүү зүйл юм. Хэрвээ тэд ямар нэгэн зүйл болохыг нүдээрээ хараагүй л бол, хэн нь ч үзлээ тавьж явуулж чаддаггүй, хэн нь ч Миний хэлсэнд итгэж чаддаггүй. Иймд тэдгээр дуулгаваргүй байдлын хөвгүүдийг шийтгэхийн тулд Би Өөрийн захиргааны зарлигийг ашигладаг.

Би ийм зүйлсийг өмнө нь хэлж байсан: Би бол Эхнийх бөгөөд Эцсийнх, мөн Би бол эхнээс нь дуусах хүртэл бүх зүйлийг хариуцдаг Нэгэн. Эцсийн өдрүүдэд Би 144,000 ялгуусан хөвгүүнийг олж авах олно. Та нар энэ “ялгуусан хөвгүүд” хэмээх үгийг шууд утгаар бага зэрэг ойлгодог боловч 144,000 гэсэн тооны талаар тодорхой

мэддэггүй. Хүний үзлээр, тоо нь хүмүүсийн эсвэл аливаа зүйлийн тоог илэрхийлдэг. “144,000 ялгуусан хөвгүүн” дэх “ялгуусан хөвгүүд”-ийг тодорхойлдог “144,000” гэдгийн тухайд бол хүмүүс 144,000 ялгуусан хөвгүүн байдаг гэж боддог. Түүнчлэн, зарим хүн энэ тоонд ямар нэг бэлгэдэл байна гэж бодон 140,000 болон 4,000-ыг тусад нь авч үздэг. Гэвч энэ хоёр тайлал нь буруу юм. Энэ нь ямар нэгэн бодит тоог илэрхийлдэггүй, ямар нэг бэлгэдэл бол бүр ч биш. Хүн төрөлхтний дунд, үүнийг ухаж ойлгож чадах хэн ч байхгүй—өнгөрсөн үеийн хүмүүс бүгд үүнийг ямар нэгэн бэлгэдэл илэрхийлсэн зүйл хэмээн боддог байсан. “144,000” гэсэн тоо нь ялгуусан хөвгүүдтэй хамаатай. Иймд 144,000 нь эцсийн өдрүүдэд хаанчлах, мөн Миний хайртай бүлэг хүмүүсийг хэлдэг. Өөрөөр хэлбэл, 144,000-ыг Сионоос ирж, Сион руу буцах бүлэг хүмүүс хэмээн тайлбарлах хэрэгтэй. 144,000 ялгуусан эрэгтэй хүүхдийн бүрэн тайлбар нь энэ юм: Тэд бол Сионоос дэлхийд ирж, Сатанаар завхруулагдсан хүмүүс бөгөөд эцэст нь Надаар дахин олж авхуулж, Надтай хамт Сион руу буцах хүмүүс юм. Миний үгээс хүн Миний ажлын алхмуудыг харж болно, өөрөөр хэлбэл, та нарын биед орох цаг тийм ч хол биш гэсэн үг юм. Иймд, Би энэ талаар та нарт ахин дахин тайлбарлаж, сануулсан. Та нар тодорхой харж, Миний үгээс хэрэгжүүлэлтийн замыг олно; Миний үгээс та нар Миний ажлын хэмнэлийг олно. Ариун Сүнсний ажлын хэмнэлийг мэдэхийн тулд Миний илчилдэг нууцуудаас та нар үүнийг ялгаж таних ёстой (учир нь Ариун Сүнсний ажлыг хэн ч харж чадахгүй, хэн ч ухаж ойлгож чаддаггүй). Ийм учраас Би нууцуудыг эцсийн өдрүүдэд илчилдэг юм.

Миний гэрт Надтай нийцдэггүй юу ч байх ёсгүй, одоогоос эхэлж Би бага багаар устгаж, цэвэрлэж эхэлнэ. Хүмүүсийн дундаас хэн ч хөндлөнгөөс оролцож чадахгүй ба хэн ч энэ ажлыг хийж чадахгүй. Энэ нь, яагаад эцсийн өдрүүдэд биечлэн ажиллаж байгааг минь илчилдэг. Ийм ч учраас Би та нарт зүгээр л цагийг сайхан өнгөрүүлэх хэрэгтэй, хуруугаа ч хөдөлгөх хэрэггүй гэж олон удаа хэлсэн юм. Үүгээр дамжуулан Миний хүч чадал, Миний зөвт байдал болон сүр жавхлан илчлэгдэж, мөн хүмүүсийн тайлж чаддаггүй Миний бүх нууц илчлэгддэг. (Хүмүүс Миний удирдлагын төлөвлөгөөний талаар ямар ч мэдлэггүй, эсвэл Миний ажлын алхмуудын талаар ямар ч ойлголтгүй байдаг учраас тэдгээрийг “нууцууд” гэж нэрлэдэг.) Эцсийн өдрүүдэд Би юу олж авах болон Би юу хийх нь нууц юм. Дэлхийг бүтээхээсээ өмнө Би өнөөдрийн хийж буй зүйлээ хэзээ ч хийж байгаагүй, хүмүүст Өөрийн суу алдарт царай юм уу үнэн биеийнхээ аль нэг хэсгийг хэзээ ч харуулж байгаагүй; харин Миний Сүнс л зарим хүн дээр ажилласан. (Бүтээлийн цагаас хойш хэн ч Намайг илтгэх чадваргүй, хэн ч Намайг илэрхийлэх чадваргүй байсан учраас Би хэнд ч үнэн биеэ харуулаагүй ба Миний Сүнс зарим хүн дээр ажилласан.) Зөвхөн өнөөдөр л Би Өөрийн суу алдарт дүрийг болон Өөрийн үнэн биеийг хүмүүст илчилж, одоо л тэд эдгээр зүйлийг харж байна. Гэвч та нарын өнөөдөр харж байгаа зүйл бас л бүрэн гүйцэд биш бөгөөд Миний та нарт харуулахыг хүссэн зүйл аанай л биш юм. Би та нарт харуулахыг хүссэн зүйл зөвхөн биед байдаг ба яг одоо хэн ч

энэ нөхцөлийг хараахан хангаагүй байна. Өөрөөр хэлбэл, бие рүү орохоос өмнө хэн ч Миний үнэн биеийг харж чадахгүй. Иймд, Сион уулан дээр Өөрийн үнэн биеийг орчлон ертөнцөд илчилнэ гэж Би хэлдэг. Үүнээс, Сион уул руу орох нь Миний төслийн хамгийн сүүлийн хэсэг гэдгийг харж болно. Сион уул руу орох цагт Миний хаанчлал амжилттай баригдах болно. Өөрөөр хэлбэл, Миний үнэн бие бол хаанчлал юм. Ууган хөвгүүд бие рүү орох цаг нь яг Миний хаанчлал бодитоор хэрэгжих цаг юм, ийм учраас ууган хөвгүүд Сион уул руу орох явдлын талаар Би ахин дахин ярьсан. Энэ бол хэний ч, хэзээ ч ойлгож ухаарч байгаагүй Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний гол цөм билээ.

Би Өөрийн ажиллах арга барилыг өөрчлөх л юм бол хүний бодлын хязгаараас давсан зүйл улам их болох учир энэ талаар болгоомжтой бай. Хүний бодлын хязгаарыг давсан зүйлс байдаг ч гэсэн Миний хэлсэн зүйл буруу гэсэн үг биш. Харин хүмүүс зовж, мөн Надтай хамтран ажиллах бүр ч их шаардлагатай гэсэн үг юм. Дур зоргоороо бүү задар, бас дан ганц өөрийн үзлийг бүү дага. Надад үйлчилдэг ихэнх хүмүүс энэ тал дээр бүдэрдэг. Хүний уг чанарыг ил гаргаж, хүний үзлийг илчлэхдээ Би Өөрийн үгийг ашиглаж байна. (Харин Надад үйлчилдэг хүмүүсийн хувьд Би тэдний үзлийг өөрчилдөггүй учир тэд зүгээр л бүдэрдэг байхад, Би үүгээр дамжуулан ууган хөвгүүдийнхээ үзлийг өөрчилж, тэдний бодлыг арилгадаг.) Иймд, эцэст нь Миний ууган хөвгүүд Миний илчилсэн нууцын ачаар бүгд төгс болгуулна.

112-Р БҮЛЭГ

“Үг болон бодит байдал зэрэгцэн явдаг” гэдэг нь Миний зөвт зан чанарын хэсэг юм. Эдгээр үгээс Би Өөрийн зан чанарыг бүгдийг нь хүн бүрд гарцаагүй харуулна. Хүмүүс үүнийг биелүүлэх боломжгүй гэж боддог ч Миний хувьд энэ нь хялбархан, таатай байдаг бөгөөд хүч чармайлт шаарддаггүй. Миний үг амнаас минь гарсан даруйд хүн бүрийн харж чадах бодит байдал бий болдог. Энэ бол Миний зан чанар. Би тодорхой зүйлсийн талаар ярьсан тул эдгээр зүйл заавал гүйцэлдэнэ. Эс бөгөөс Би ярихгүй байх байсан. Хүний үзлээр бол “аврал” гэдэг үгийг хүн бүрд хэлдэг, гэхдээ энэ нь Миний санаа зорилготой нийцдэггүй. Урьд нь Би “Мэдлэггүй агаад зүтгэлтэй эрэлчдийг Би үргэлж авардаг” гэж хэлсэн. Энд буй “аврах” гэдэг нь Надад үйлчлэл үзүүлдэг хүмүүсийг хэлсэн бөгөөд Би ийм үйлчлэл үзүүлэгчдэд онцгой анхаарал тавина гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл, Би тийм хүмүүсийн шийтгэлийг бууруулна. Хэдий тийм ч, шударга бус, ов мэхтэй энэ үйлчлэл үзүүлэгчид нь сүйрлийн бай дунд байдаг, өөрөөр хэлбэл, Би тэдэнд хатуу шийтгэл тулгах болно. (Хэдийгээр тэд сүйрлийн бай дунд байгаа ч устгагдах хүмүүсээс маш өөр: Тэд мөнхийн хатуу шийтгэл хүлээж авах бөгөөд тэр хүмүүсийн хүлээж авах шийтгэл нь диавол Сатаны шийтгэл юм. Мөн, тэр хүмүүс бол агуу улаан лууны үр удам гэж

хэлсний минь жинхэнэ утга учир энэ юм.) Гэхдээ Би ууган хөвгүүдийнхээ талаар ийм үг ашигладаггүй; тэдний тухайд бол Би ууган хөвгүүдээ буцаан авч, тэд Сион руу дахин нэгэнтээ буцах болно гэж хэлдэг. Тиймээс, Миний ууган хөвгүүд бол Миний урьдчилан тогтоож, сонгосон хүмүүс юм гэдгийг Би үргэлж хэлсэн. Миний ууган хөвгүүд анх Надад харьяалагдаж, Надаас үүссэн, иймээс тэд энд Над дээр буцаж ирэх ёстой. Мөн хөвгүүд болон ардуудыг ууган хөвгүүдтэй харьцуулбал үнэхээр тэнгэр газар шиг ялгаатай байдаг: Хэдийгээр хөвгүүд болон ардууд үйлчлэл үзүүлэгчдээс хамаагүй дээр ч гэсэн Надад харьяалагддаг хүмүүс яавч биш юм. Хөвгүүд болон ардуудыг хүн төрөлхтний дундаас нэмж сонгосон гэж хэлж болно. Иймд, Өөрийн эрч хүчийг Би үргэлж ууган хөвгүүд дээрээ төвлөрүүлсэн ба дараа нь ууган хөвгүүдээр энэ хөвгүүд болон ардуудыг бүрэн төгс болгуулах болно. Эдгээр нь Миний ирээдүйн ажлын алхмууд юм. Одоо та нарт хэлээд ямар ч нэмэргүй учраас Би үүнийг хөвгүүд болон ардуудад ховорхон дурдсан, харин зөвхөн ууган хөвгүүдэд л Би эдгээрийг ахин дахин ярьж, удаа дараа дурдсан. Энэ бол Миний ярьж, ажилладаг зам юм. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, ганцхан Би л бүх зүйлийн талаар эцсийн шийдвэр гаргадаг.

Өдөр бүр Би та нарын үзлийн эсрэг тулалдаж, өдөр алгасалгүй та нарыг нэг бүрчлэн задлан шинжилж байна. Намайг тодорхой хэмжээнд ярих үед та нар хуучиндаа орж, Миний хүн чанарыг Миний бурханлаг чанараас дахин салгадаг. Энэ үед, хүмүүсийн илчлэгдэх цаг ирсэн: Хүмүүс Намайг махбодод амьдарсаар байгаа бөгөөд Бурхан Өөрөө огтоос биш, Би бол хүн, Бурхан бол Бурхан, хүн болох Надтай Бурхан ямар ч хамаагүй хэмээн боддог. Энэ хүн төрөлхтөн хэчнээн ялзарсан юм бэ! Би өмнө нь маш олон үг хэлсэн боловч та нар аль эртнээс тэдгээрийг оршин байдаггүй мэт үзсэн, үүнээс болж Би та нарыг голдоо ортол үзэн яддаг! Үнэхээр үүнээс болоод Би та нарыг зэвүүцдэг! Бүрэн гүйцэд Бурхан Өөрөө Надад, хүн чанар болон бүрэн бурханлаг чанартай Надад хэн санаандгүй халдаж зүрхлэх вэ? Хэн Намайг бодолдоо эсэргүүцэж зүрхлэх вэ? Миний аюулт гамшиг бууж эхэлсний дараа Би тэднийг нэг нэгээр нь шийтгэнэ, хэнийг нь ч үлдээхгүй, харин бүгдийг нь хатуу шийтгэнэ. Миний Сүнс биечлэн ажилладаг. Энэ нь Би бол Бурхан Өөрөө биш гэсэн үг биш; харин ч эсрэгээрээ Би бол төгс хүчит Бурхан Өөрөө бүр ч мөн гэсэн утгатай юм. Хүмүүс Намайг мэддэггүй—бүгд Намайг эсэргүүцдэг, Миний үгээс бүхнийг чадагч байдлыг минь олж хардаггүй, харин оронд нь Миний эсрэг ашиглах зүйлийг Миний үгээс олж, Надаас алдаа олохоор оролддог. Нэг л өдөр ууган хөвгүүдийн хамт Сионд гарч ирэхдээ Би эдгээр зүйлтэй харьцаж эхэлнэ. Энэ хугацаанд Би үндсэндээ энэ ажлыг хийж байгаа. Намайг тодорхой хэмжээнд ярих үед олон тооны үйлчлэл үзүүлэгч ухарсан байх ба ууган хөвгүүд ч бас төрөл бүрийн бэрхшээл амссан байх болно. Ажлын энэ хоёр алхмын ахиц дэвшилтэй хамт Миний ажлын үе шат төгсгөлдөө очно. Үүний зэрэгцээ Би ууган хөвгүүдээ Сион руу буцаан авааchна. Эдгээр нь Миний ажлын алхмууд юм.

Миний ууган хөвгүүд бол Миний хаанчлалын салшгүй хэсэг бөгөөд Миний үнэн

бие бол үнэн хэрэгтээ хаанчлал—Миний ууган хөвгүүд төрсний дараа Миний хаанчлал бий болсон гэдгийг үүнээс харж болно. Өөрөөр хэлбэл, Миний хаанчлал дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш оршин тогтнож байгаа бөгөөд Өөрийн ууган хөвгүүдийг олж авах (Өөрийн ууган хөвгүүдийг буцаан авах гэсэн үг) гэдэг нь Өөрийн хаанчлалыг сэргээх явдал юм. Үүнээс, ууган хөвгүүд нэн чухал ач холбогдолтой гэдгийг харж болно. Миний ууган хөвгүүд л оршин байвал хаанчлал бий болж, эрх мэдэлтэйгээр хаанчлах бодит байдал биеллээ олж, шинэ амь үүсэж, хуучин эрин үе бүхэлдээ төгсөх болно. Энэ бол зайлшгүй чиг хандлага юм. Ууган хөвгүүд ийм байр сууринд байдаг учраас дэлхийн сүйрэл, Сатаны мөхөл, үйлчлэл үзүүлэгчдийн үнэн дүр төрхийн илчлэл, мөн агуу улаан луу үр удамгүй болж, гал болон хүхэрт нуур луу буух баримтыг бэлгэддэг—тиймээс эрх мэдэл эзэмшдэг хүмүүс болон агуу улаан лууны үр удам бүгд ахин дахин саад хийж, эсэргүүцэж, сүйтгэдэг. Харин Би ууган хөвгүүдээ ахин дахин дэмжиж, гэрчилж, илчилдэг. Учир нь Надаас ирсэн хүмүүс л Миний төлөө гэрчлэл хийх эрхтэй; гагцхүү тэд л Намайг амьдран харуулах шаардлагыг хангадаг, гагцхүү тэд л тулаанд тулалдаж, Миний төлөө сайхан ялалт авчрах суурьтай. Надаас тусдаа байгаа хүмүүс бол Миний гар дахь жаахан шавраас цаашгүй—дор бүрнээ бүтээгдсэн зүйл юм. Хөвгүүд болон ардууд нь бүтээлүүдийн дундаас арай сайн нь гэж сонгогдсоноос цаашгүй, гэхдээ тэд Надад харьяалагддаггүй. Иймд, ууган хөвгүүд болон хөвгүүдийн хооронд үлэмж ялгаа байдаг. Хөвгүүдийг ууган хөвгүүдтэй харьцуулахад огтхон ч тохирохгүй—ууган хөвгүүд тэднийг захирч, ноёлдог. Одоо та нар үүнийг тов тодорхой мэддэг байх ёстой! Миний хэлсэн үг бүр үнэн бөгөөд яавч худал биш. Энэ бүхэн Миний үнэн биеийн илэрхийллийн хэсэг, Миний айлдвар юм.

Би хоосон үг хэлдэггүй гэдгээ хэлсэн ба Би алдаа гаргадаггүй; энэ нь Миний сүр жавхланг хангалттай харуулдаг. Гэтэл хүмүүс сайныг муугаас нь ялгаж чаддаггүй, Миний гэсгээлт өөрсдөд нь тохиолдсоны дараа л бүрэн үнэмшдэг; эс бөгөөс тэд тэрслүү, дур зоргоороо хэвээр үлддэг. Ийм учраас бүх хүн төрөлхтний эсрэг тулалдахдаа Би гэсгээлт ашигладаг. Хүний үзлээр бол, цорын ганц Бурхан Өөрөө байдаг байхад Надаас гарсан ууган хөвгүүд яагаад маш олон байна вэ? Би үүнийг ингэж хэлж чадна: Өөрийнхөө хувийн хэрэг явдлын талаар Би хүссэнээрээ ярьдаг. Хүн Надад юу хийж чадах юм бэ? Би үүнийг ч бас ингэж хэлж чадна: Хэдийгээр ууган хөвгүүд болон Би адилхан дүр төрхтэй биш боловч бид нэг Сүнстэй тул тэд нэгэн сэтгэлээр Надтай хамтран ажиллаж чадна. Миний үнэн биеийн хэсэг бүрийг бүх хүн туйлын тодорхой хараасай гэсэндээ бид адилхан дүр төрхтэй биш байдаг. Ийм учраас Би бүх улс үндэстэн, бүх ард түмнийг Надтай хамт удирдахыг ууган хөвгүүддээ зөвшөөрдөг. Энэ бол Миний захиргааны зарлигийн төгсгөлийн хэсэг юм (Миний ярьдаг энэхүү “төгсгөлийн хэсэг” нь Миний дууны өнгө намдуу зөөлөн бөгөөд Би хөвгүүд, ардуудтайгаа ярьж эхэлсэн гэсэн утгатай). Ихэнх хүмүүс энэ талаар эргэлздэг ч тэд хэт их эргэлзэх шаардлагагүй. Хүмүүсийг ичээж, нүүр хийх газаргүй болгох үүднээс Би хүмүүсийн бүх үзлийг нэг нэгээр нь ил болгоно. Би

орчлон ертөнц, газар дэлхийн зах хязгаараар аялж, орчлон ертөнцийг бүхэлд нь ажигладаг. Би төрөл бүрийн хүнийг шалгадаг—Миний хяналтаас зугтаж чадах хэн ч байхгүй. Би бүх төрлийн зүйлд оролцдог, Миний биечлэн зохицуулдаггүй зүйл гэж байхгүй. Хэн Миний бүхнийг чадагч байдлыг үгүйсгэж зүрхлэх билээ? Хэн Надад бүрэн үнэмшихгүй байж зүрхлэх билээ? Хэн Миний өмнө нүүрээрээ газар унан мөргөхгүй байж зүрхлэх билээ? Миний ууган хөвгүүдээс болж бүх тэнгэр өөрчлөгдөнө, үүнээс ч илүүтэйгээр Надаас болон Миний ууган хөвгүүдээс болж бүх газар дэлхий хүчтэй хөдлөх болно. Миний үнэн биеийн өмнө бүх хүн сөхөрч, бүх зүйл өчүүхэн ч алдаа мадаггүйгээр Миний гарын хяналтад орно. Хүн бүхэн бүрэн дүүрэн үнэмшиж, бүх зүйл Миний гэрт ирж, Надад үйлчлэх ёстой. Энэ бол Миний захиргааны зарлигийн сүүлчийн хэсэг юм. Өөр өөр хүмүүсийг онилж байгаа Миний захиргааны зарлигийн заалт бүр одоогоос эхлэн үр дүнд хүрч эхэлнэ (учир нь Миний захиргааны зарлиг олон нийтэд бүрэн ил болж, төрөл бүрийн хүн болон бүх зүйлд тохирох зохицуулалт хийгдсэн. Миний захиргааны зарлигаас болж бүх хүн өөрсдөдөө тохирсон газар байж, төрөл бүрийн хүний үнэн дүр төрх ил болох болно). Ийнхүү жинхэнэ, бодит захиргааны зарлиг ирнэ.

Одоо Би Өөрийн ажлын алхамд нийцүүлэн хэлэхийг хүссэн зүйлээ хэлдэг бөгөөд Миний үгийг хүн бүр ноцтой хүлээн авах ёстой. Эрин үеүдийн туршид, ариун хүн бүрийн ам “Шинэ Иерусалимын” тухай хэлсэн, хүн бүр үүнийг мэддэг боловч хэн ч энэ нэр томьёоны жинхэнэ утгыг ойлгодоггүй. Өнөөдрийн ажил энэ шат хүртэл явагдсан болохоор та нарт ойлгуулах үүднээс Би энэ нэр томьёоны жинхэнэ утгыг илчилнэ. Гэхдээ Миний илчлэлд хязгаар бий—Би үүнийг яаж ч тайлбарласан, яаж ч тодорхой хэлсэн бай, та нар үүнийг хэзээ ч бүрэн ойлгож чадахгүй, учир нь энэ нэр томьёоны бодит байдалд хэн ч хүрч чадахгүй. Урьд нь, газар дээр Миний оршин суудаг газрыг буюу Миний алхаж, явдаг газрыг Иерусалим гэдэг байв. Харин “шинэ” гэх үг энэ нэр томьёог өөрчилдөг бөгөөд энэ нь одоо өмнөхтэйгөө огт адилгүй болсон. Хүмүүс үүнийг өчүүхэн төдий ч ойлгож чадахгүй. Зарим хүн үүнийг Миний хаанчлалыг хэлж байна гэж боддог; зарим хүн энэ бол хүн болох Би гэж боддог; зарим хүн үүнийг шинэ тэнгэр, газар гэж боддог; зарим нь үүнийг, энэ ертөнцийг устгасны минь дараа бий болох шинэ дэлхий ертөнц гэж боддог. Хүний оюун санаа хэтэрхий төвөгтэй, баялаг төсөөлөлтэй хэдий ч тэрээр энэ талаар мөн л юу ч ойлгож чадахгүй. Эрин үеүдийн турш, хүмүүс энэ нэр томьёоны жинхэнэ утгыг мэдэж, эсвэл харах гэж найдсаар ирсэн ч хүслээ биелүүлж чадаагүй—тэд бүгд сэтгэлээр унацгааж, хүсэл эрмэлзлээ орхиод өөд болсон; Миний цаг хараахан ирээгүй учир Би үүнийг хэнд ч амархан хэлж чадаагүй. Миний ажил нэгэнт энэ үе шат хүртэл хийгдсэн тул Би та нарт бүхнийг хэлнэ. Шинэ Иерусалим нь Миний уур хилэн, Миний захиргааны зарлиг, Миний хаанчлал болон ууган хөвгүүддээ хайрладаг Миний хязгааргүй ерөөлүүд гэсэн энэ дөрвөн зүйлээс бүрддэг. “Шинэ” гэдэг нэр томьёо ашигладгийн минь шалтгаан гэвэл энэ дөрвөн хэсэг нуугдмал байдгаас болдог. Миний уур хилэн, Миний захиргааны зарлигийг хэн ч мэддэггүй,

Миний хаанчлалыг хэн ч хараагүй, Миний ерөөлүүдийг хэн ч эдлээгүй учраас “шинэ” гэдэг нь нуугдмал зүйлийг хэлдэг. Миний хэлсэн зүйлийг хэн ч бүрэн ойлгож чадахгүй, учир нь Шинэ Иерусалим газарт бууж ирсэн боловч Шинэ Иерусалимын бодит байдлыг хэн ч биеэр туулаагүй. Би үүний талаар хэчнээн бүрэн гүйцэд ярилаа ч хүмүүс бүрэн ойлгохгүй. Хэн нэгэн ойлголоо ч гэсэн, энэхүү ойлголт нь зөвхөн тэдний үг, тэдний оюун ухаан, тэдний үзэл юм. Энэ бол зайлшгүй чиг хандлага; энэ бол цорын ганц зам бөгөөд хэн ч үүнээс салж чадахгүй.

113-Р БҮЛЭГ

Миний хийдэг үйлдэл бүрд Миний мэргэн ухаан байдаг ч хүн үүнийг огтхон ч ухан ойлгож чадахгүй; хүн Миний үйлдэл, Миний үгийг л харж чаддаг боловч хүнд үндсэндээ ийм чадвар байдаггүй учраас Миний алдар юм уу Миний үнэн биеийн дүр төрхийг харж чаддаггүй. Иймээс, Би хүнийг өөрчлөлгүйгээр ууган хөвгүүдтэйгээ хамт Сионд эргэн ирж, дүр төрхөө өөрчилнө, ингэснээр хүн Миний мэргэн ухаан, бүхнийг чадагч байдлыг харна. Хүний одоо харж буй Миний мэргэн ухаан, бүхнийг чадагч байдал бол Миний алдрын нэг жаахан хэсэг төдий—үүнийг дурдахын ч хэрэггүй. Миний мэргэн ухаан болон Миний алдар хязгааргүй—хэмжээлшгүй гүнзгий—хүний оюун санаа үүнийг бодож, ойлгож огт чадахгүй гэдгийг үүнээс харж болно. Хаанчлалыг байгуулах нь ууган хөвгүүдийн үүрэг, энэ нь бас Миний ажил. Өөрөөр хэлбэл, энэ нь Миний удирдлагын төлөвлөгөөний нэг зүйл юм. Хаанчлалыг барьж байгуулах нь чуулганыг барьж байгуулахтай адилгүй; Миний ууган хөвгүүд болон Би бол Миний үнэн бие, хаанчлал тул Миний ууган хөвгүүд болон Намайг Сион ууланд орох үед хаанчлалын бүтээн байгуулалт дууссан байх болно. Өөрөөр хэлбэл, хаанчлалын бүтээн байгуулалт гэдэг нь ажлын нэг алхам—сүнсний ертөнцөд орох алхам юм. (Гэхдээ, дэлхийг бүтээснээс хойш Миний хийсэн бүхэн энэ алхмын төлөө байсан. Хэдийгээр Би үүнийг алхам гэдэг ч үнэн хэрэгтээ энэ нь алхам огтхон ч биш юм.) Тиймээс Би бүх үйлчлэл үзүүлэгчийг энэ алхамд үйлчлүүлэхэд ашигладаг ба үүнээс үүдэн эцсийн өдрүүдэд олон тооны хүн ухарна; тэд бүгд ууган хөвгүүдэд үйлчлэл үзүүлдэг. Үйлчлэл үзүүлэгчдэд сайхан сэтгэлээр ханддаг хэн ч бай Миний хараалаар үхэх болно. (Үйлчлэл үзүүлэгчид бүгд агуу улаан лууны явуулгыг төлөөлдөг ба бүгдээрээ Сатаны зарц тул энэ хүмүүст сайхан сэтгэлээр ханддаг хүмүүс бол агуу улаан лууны хамсаатан бөгөөд Сатанд харьяалагддаг.) Би хайрладаг бүхнээ хайрлаж, Өөрийн хараал болон шатаалтын бүх байг үзэн яддаг. Та нар ч бас ингэх чадах уу? Миний эсрэг зогсдог хэнийг ч Би лавтайяа өршөөхгүй, зүгээр ч орхихгүй! Үйл хэрэг бүрийг хийхдээ Би Надад үйлчлэх олон тооны үйлчлэл үзүүлэгчийг зохицуулдаг. Тиймээс, түүхэн туршид эш үзүүлэгчид болон элч нар өнөөдрийн алхмын төлөө үйлчлэл үзүүлсэн ба тэд Миний зүрх сэтгэлийн дагуу байгаагүй, мөн Надаас ирээгүй гэдгийг харж болно.

(Хэдийгээр тэдний ихэнх нь Надад үнэнч боловч хэн нь ч Надад харьяалагддаггүй. Иймд тэдний хааяагүй гүйж байгаа нь Надад зориулан энэ эцсийн алхмын суурийг тавихын төлөө байдаг боловч тэдний хувьд энэ бүхэн нь хий дэмий хичээл чармайлт юм.) Тиймээс, эцсийн өдрүүдийн үеэр бүр ч олон тооны хүн ухарна. (Би яагаад “олон тооны” гэж хэлдэг вэ гэвэл Миний удирдлагын төлөвлөгөө хэдийнээ төгсгөлдөө хүрч, Миний хаанчлалын бүтээн байгуулалт амжилт олж, ууган хөвгүүд сэнтийд суусан.) Энэ бүхэн нь ууган хөвгүүд гарч ирснээс болж байгаа юм. Ууган хөвгүүд гарч ирсэн учраас агуу улаан луу хохирол учруулахын тулд элдэв аргаар оролдож, чадах бүхнээ хийн, Миний төлөө үйлчлэл хийхээр ирдэг, одоо үед үнэн царайгаа харуулсан, Миний удирдлагын төлөвлөгөөг тасалдуулахаар оролдсон бүх төрлийн муу ёрын сүнсийг илгээдэг. Эдгээрийг энгийн нүдээр харж чадахгүй; энэ нь бүгд сүнсний ертөнцийн зүйлс юм. Иймд, ухрах хүмүүс олон байх болно гэдэгт хүмүүс итгэдэггүй ч юу хийж байгаа Би мэддэг, Өөрийнхөө удирдлагыг Би ойлгодог; энэ бол хүнийг хөндлөнгөөс оролцуулдаггүйн шалтгаан юм. (Нэг л өдөр бүх төрлийн садар самуун муу ёрын сүнснүүд жинхэнэ төрхөө илчилж, бүх хүн чин сэтгэлээсээ үнэмшинэ.)

Би ууган хөвгүүдээ хайрладаг боловч Намайг чин сэтгэлээсээ хайрладаг агуу улаан лууны үр удмыг огтхон ч хайрладаггүй; үнэндээ Би тэднийг бүр ч их үзэн яддаг. (Энэ хүмүүс Минийх биш, хэдийгээр тэд сайн санаа зорилго харуулж, сайхан үг хэлдэг боловч энэ нь бүгд агуу улаан лууны явуулга тул Би тэднийг голдоо ортол үзэн яддаг.) Энэ бол Миний зан чанар, Миний зөвт байдал бүхлээрээ билээ. Хүн үүнийг огтхон ч ухан ойлгож чадахгүй. Яагаад энд Миний зөвт байдал бүхэлдээ илчлэгдэв? Үүнээс хүн ямар ч халдлагыг тэвчдэггүй Миний ариун байдлыг ухамсарлаж болно. Би ууган хөвгүүдээ хайрлаж, Миний ууган хөвгүүд биш бүх хүнийг (тэд үнэнч хүмүүс байлаа ч гэсэн) үзэн ядаж чадна. Энэ бол Миний зан чанар. Та нар харж чадахгүй байна уу? Хүмүүсийн үзлээр Би бол үргэлж өршөөнгүй Бурхан, мөн Намайг хайрладаг хэнийг ч Би хайрладаг; энэ тайлбар нь Миний эсрэг доромжлол биш гэж үү? Би араатан амьтдыг хайрлаж чадах уу? Би Сатаныг Өөрийн ууган хүү болгон таалж чадах уу? Утгагүй юм! Миний ажил Миний ууган хөвгүүд дээр л явагддаг, Миний ууган хөвгүүдээс өөр хайрлах зүйл Надад үгүй. (Хөвгүүд, ардууд бол нэмэлт боловч чухал биш.) Хүмүүс Намайг маш их хэрэггүй ажил хийдэг байсан хэмээн хэлдэг ч Миний үзэл бодлоор бол тэр ажил үнэнлээ хамгийн үнэ цэнтэй, хамгийн утга учиртай байсан. (Энэ нь хоёр удаа бие махбодтой болох үеэр хийгдсэн ажлыг бүхэлд нь хэлж байна; Би сүр хүчээ илчлэхийг хүсдэг учир Өөрийн ажлыг гүйцэлдүүлэхийн тулд махбод болох ёстой.) Миний Сүнс биечлэн ажиллахаар ирдэг гэж хэлдгийн минь шалтгаан нь Миний ажлыг махбодоор гүйцэлдүүлдгээс болдог. Өөрөөр хэлбэл, Би болон Миний ууган хөвгүүд амралтад орж эхэлдэг. Махбодоор Сатантай дайтах нь сүнсний ертөнцөд Сатантай дайтсанаас илүү ширүүн байдаг; үүнийг бүх хүн харж чадах тул Сатаны үр удам ч гэсэн Надад сайхан гэрчлэл хийж чадах ба орхиж явахыг хүсдэггүй; энэ нь

махбодод ажилладгийн минь утга учир юм. Энэ нь үндсэндээ диаволын үр удмаар диаволыг өөрийг нь гутаалгахын төлөө байдаг; энэ бол диавол Сатанд тохиолдох хамгийн том шившиг бөгөөд нүүр хийх газаргүй болтлоо ичиж, Миний өмнө ахин дахин өршөөл гуйхад түүнийг хүргэдэг. Би Өөрийн ууган хөвгүүдтэй хамт гэр бүлийн аз жаргалыг эдэлж, тэнгэрийн хаанчлалын агуу найранд үүрд умбахын тулд Би ялсан, Би бүх зүйлийг даван туулсан, Би гуравдагч тэнгэрийг нэвтлэн гарч, Сион ууланд хүрсэн!

Ууган хөвгүүдийнхээ төлөө Би төлөөс бүрийг төлж, бүх хичээл чармайлтаа зориулсан. (Миний хийсэн бүхэн, Миний хэлсэн бүхэн, Би бүх төрлийн муу ёрын сүнсийг нэвт харж, бүх төрлийн үйлчлэл үзүүлэгчдийг зайлуулсан нь бүгд ууган хөвгүүдийн төлөө байсан гэдгийг хүн ердөө мэддэггүй.) Гэхдээ энэ их ажлын дунд Миний зохицуулалт эмх цэгцтэй байдаг; ажлыг хэзээ ч сохроор хийдэггүй. Миний өдөр бүрийн үгээс та нар Миний ажлын арга барил, алхмуудыг харж чаддаг байх ёстой; Миний өдөр тутмын үйлдлээс аливаа хэрэг явдалтай харьцах Миний мэргэн ухаан, Миний зарчмуудыг олж харах ёстой. Миний хэлснээр, Сатан Миний удирдлагыг тасалдуулах зорилгоор Надад үйлчлэл үзүүлдэг тэр хүмүүсийг илгээсэн. Эдгээр үйлчлэл үзүүлэгч бол үрийн сүүл, гэхдээ “буудай” гэдэг нь ууган хөвгүүдийг хэлдэггүй, харин ууган хөвгүүд бус хөвгүүд, ардуудыг бүгдийг нь хэлдэг. “Буудай үргэлж буудай байна, үрийн сүүл үргэлж үрийн сүүл байна”; энэ нь Сатаны хүмүүсийн уг чанар хэзээ ч өөрчлөгдөж чадахгүй гэсэн үг юм. Иймээс, товчхондоо тэд Сатан хэвээр үлддэг. “Буудай” гэж хөвгүүд, ардуудыг хэлдэг, учир нь дэлхий ертөнцийг бүтээхээсээ өмнө Би энэ хүмүүст Өөрийн чанарыг шингээсэн. Би өмнө нь хүний уг чанар өөрчлөгддөггүй гэж Би аль хэдийн хэлсэн, тиймээс буудай үргэлж буудай л байх болно. Тэгвэл ууган хөвгүүд нь юу вэ? Ууган хөвгүүд Надаас ирдэг; Би тэднийг бүтээгээгүй тул буудай гэж нэрлэж болохгүй (учир нь буудайн талаар дурдах нь “үр тарих” гэдэг үгтэй үргэлж холбогддог бөгөөд “үр тарих” гэдэг нь “бүтээх” гэсэн утгатай; үйлчлэл үзүүлэгчээр ажиллуулахын тулд Сатан бүх үрийн сүүлийг нууцаар тарьдаг). Ууган хөвгүүд бол Миний үнэн биеийн бүрэн төгс, элбэг илрэл юм; тэднийг алт, мөнгө болон үнэт чулуугаар төлөөлүүлэх хэрэгтэй гэж хэлж л болно. Би хулгайч мэт ирнэ гэсэн баримтыг энэ нь хөнддөг ба Би алт, мөнгө, үнэт чулуунуудыг хулгайлахаар ирсэн билээ (учир нь эдгээр алт, мөнгө, үнэт чулуу анхнаасаа Надад харьяалагдаж байсан бөгөөд Би тэднийг Өөрийн гэр лүү буцаан аваачихыг хүсдэг). Ууган хөвгүүдийн хамт Сионд эргэн очих үедээ Би эдгээр алт, мөнгө, үнэт чулууг хулгайлсан байх болно. Энэ үед, Сатаны саад тотгор, үймээн бий болох тул Би алт, мөнгө, үнэт чулуунуудыг авч, Сатаны эсрэг шийдвэрлэх тулааныг эхлүүлнэ. (Энд Би мэдээж үлгэр ярьж байгаа юм биш; энэ бол сүнсний ертөнц дэх үйл явдал учраас хүмүүс энэ талаар тийм ч тодорхой мэддэггүй, үлгэр мэт сонсож л чадна. Харин та нар Миний зургаан мянган жилийн төлөвлөгөө гэж юу болохыг Миний үгээс харах ёстой бөгөөд үүнийг яасан ч хошигнол мэт авч үзэх ёсгүй. Эс бөгөөс Миний Сүнс бүх хүнийг орхин явах болно.) Өнөөдөр, энэ тулаан

бүрмөсөн дууссан бөгөөд Би Өөрийн ууган хөвгүүдтэй хамт (Надад харьяалагддаг алт, мөнгө, үнэт чулуунуудыг аваад) Сион уул руугаа буцах болно. Алт, мөнгө, үнэт чулуунууд ховорхон, үнэ цэнтэй байдгаас болоод Сатан тэднийг булааж авахын тулд боломжтой бүх аргаар оролддог ч Надаас гарсан зүйл Надад эргэн ирэх ёстой гэж Би ахин дахин хэлдэг бөгөөд үүний утга учрыг дээр дурдсан. Ууган хөвгүүд Надаас ирдэг, Надад харьяалагддаг гэдэг Миний үг бол Сатанд өгч буй тунхаглал мөн. Үүнийг хэн ч ойлгодоггүй, энэ нь бүхэлдээ сүнсний ертөнцөд л тохиолддог асуудал юм. Тиймээс Миний ууган хөвгүүд Надад харьяалагддаг гэж ахин дахин онцолдгийг минь хүн ойлгодоггүй; өнөөдөр та нар ойлгох ёстой! Миний үг зорилготой, мэргэн ухаантай гэж Би хэлсэн, харин та нар үүнийг гадна талаас нь л ойлгодог—хэн ч үүнийг сүнсэн дотроос тодорхой харж чадахгүй.

Би улам их ярьж, ярих тусам Миний үг улам хатуу ширүүн болдог. Үүнийг тодорхой түвшинд хүрэх үед Би үгээ ашиглан хүмүүсийг тодорхой түвшинд боловсруулж, зөвхөн зүрх сэтгэлдээ ч биш, бас үгээрээ үнэмшихэд хүргээд зогсохгүй, тэднийг амьдрал, үхлийн хооронд эргэлдүүлнэ; энэ бол Миний ажлын арга барил, Миний ажлын алхам. Энэ нь ийм л байх ёстой; тэгсэн цагт л Сатаныг шившиглэж, ууган хөвгүүдийг бүрэн төгс болгож (Өөрийн үгийг ашиглан ууган хөвгүүдийг эцэст нь төгс болгож, махан биеэс ангижруулж, сүнсний ертөнцөд оруулж) чадна. Хүн Миний үгийн арга барил, дууны өнгийг ойлгодоггүй. Миний тайлбараас та бүхэн мэдлэг ухаантай болох ёстой ба хийх ёстой ажлаа гүйцээхийн тулд Миний үгийг бүгд дагах ёстой. Энэ бол та нарт Миний даалгасан зүйл. Та нар зөвхөн гадаад ертөнцөөс төдийгүй, хамгийнчухал нь сүнсний ертөнцөөс үүнийг мэддэг байх ёстой.

114-Р БҮЛЭГ

Би энэ орчлон ертөнцийг бүтээсэн; Би уулс, гол мөрөн, бүх зүйлийг бүтээсэн; Би орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаарыг бүтээсэн; Би Өөрийн хөвгүүд болон ардуудыг хөтөлсөн; Би бүх зүйл болон хэрэг явдлыг удирдсан. Одоо, Би Өөрийн ууган хөвгүүдийг хөтлөн Сион уул руугаа, Өөрийнхөө амьдардаг газар луу буцах бөгөөд энэ нь Миний ажлын эцсийн алхам байх болно. Миний хийсэн бүхэн (бүтээлийн цагаас эхлээд одоог хүртэл хийсэн юм бүхэн) Миний ажлын өнөөдрийн үе шатны төлөө байсан бөгөөд тэр тусмаа маргаашийн засаглал, маргаашийн хаанчлал, Би болоод Миний ууган хөвгүүдийн үүрдийн баяр цэнгэлийн төлөө юм. Энэ бол бүх зүйлийг бүтээх Миний зорилго, бүтээлээрээ дамжуулан эцэст нь гүйцэлдүүлэх зүйл минь байх болно. Миний хэлдэг, хийдэг зүйлд зорилго, төлөвлөгөө бий; юуг ч санаандгүй хийдэггүй. Миний хувьд бүх зүйл эрх чөлөөтэй, юунд ч баригддаггүй гэж Би хэлдэг ч, Миний хийдэг бүх зүйл зарчимтай бөгөөд Миний хийдэг бүхэн Миний мэргэн ухаан болон зан чанар дээр суурилдаг. Та нарт

энэ талаар мэдлэг ухаан байна уу? Бүтээлийн цагаас эхлээд өнөөг хүртэл, Миний ууган хөвгүүдээс өөр хэн ч Намайг мэдэж аваагүй, хэн ч Миний жинхэнэ царайг харж байгаагүй. Миний ууган хөвгүүд гэж онцгойлон үзэж байгаагийн учир нь тэд бол үндсэндээ Миний үнэн биеийн нэг хэсэг билээ.

Би дэлхийг бүтээхдээ Өөрийн шаардлагын дагуу хүнийг дөрвөн эрэмбэлсэн ангилалд хуваасан, эдгээр нь: Миний хөвгүүд, Миний ардууд, үйлчлэл үзүүлэгчид болон мөхөх хүмүүс. Яагаад Миний ууган хөвгүүд энэ жагсаалтад багтаагүй вэ? Учир нь Миний ууган хөвгүүд бүтээгдсэн зүйлс биш; тэд Надаас ирсэн болохоос хүн төрөлхтнийх биш. Би махбод болохоосоо өмнө Өөрийн ууган хөвгүүдэд зориулан зохицуулалт хийсэн; тэд ямар гэр бүлд төрөх, хэн тэдэнд үйлчлэх гээд энэ бүх зүйлийг Би төлөвлөсөн. Мөн Би ямар цаг үед тэдний хэнийг нь буцаан олж авахаа төлөвлөсөн бөгөөд эцэст нь бид Сион руу хамтдаа буцна. Энэ бүгдийг бүтээлээс өмнө төлөвлөсөн тул үүнийг хэн ч мэддэггүй, ямар ч номд бичигдээгүй, учир нь энэ бол Сионы хэрэг юм. Түүнчлэн, Би махбод болохдоо хүнд энэ чадварыг өгөөгүй учраас хэн ч эдгээрийг мэдээгүй юм. Сион руу буцахдаа та нар өнгөрсөнд ямар байснаа, одоо ямар байгаагаа болон энэ амьдралдаа юу хийснээ мэдэх болно. Яг одоо, Би зүгээр л та нарт эдгээрийг ил тод, бага багаар ярьж байгаа юм, эс бөгөөс та нар хэчнээн их хүчин чармайлт гаргалаа ч ойлгохгүй, Миний удирдлагад саад болох болно. Өнөөдөр, хэдийгээр Би махбодын хувьд Өөрийн ихэнх ууган хөвгүүдээс салсан ч гэсэн, бид бол нэг Сүнстэй бөгөөд бидний бие махбодын гадаад төрх өөр байж болох ч, эхнээсээ төгсгөл хүртэл бид нэг Сүнс билээ. Хэдий тийм байлаа ч, Сатаны үр удам үүнийг завших боломж болгон ашиглаж болохгүй. Чи яаж ч өнгөлөн далдалсан бай, энэ нь өнгөц хэвээр үлддэг ба Би үүнийг сайшаахгүй. Иймээс, өнгөц байдалд анхаарч, гаднаа Намайг дуурайхыг хичээдэг хүмүүс бол зуун хувь Сатан байх нь тодорхой гэдгийг үүнээс харж болно. Тэдний сүнс өөр, тэд Миний хайртай хүмүүсийн нэг биш учир Намайг хэчнээн дуурайлаа ч Надтай төсгүй. Түүнчлэн, Миний ууган хөвгүүд угаасаа Надтай нэг Сүнстэй учир, Намайг дуурайгаагүй байлаа ч, Надтай адилхан байдлаар ярьж, үйлддэг, бүгд үнэнч, цэвэр ариун, нээлттэй юм (энэ хорвоо дээрх туршлага нимгэн учраас энэ хүмүүс мэргэн ухаанаар дутуу дулимаг байдаг учраас мэргэн ухаан дутагдах нь Миний ууган хөвгүүдэд дутагдал биш; тэд биед буцаж ороход бүх зүйл сайхан болно). Иймд, дээр дурдсан шалтгааны улмаас Би тэдэнтэй яаж ч харьцсан, ихэнх хүн улиг болсон уг чанараа өөрчилдөггүй. Харин Миний ууган хөвгүүдийн хувьд, Би тэдэнтэй харьцах шаардлагагүйгээр Миний хүсэлд нийцдэг, учир нь бид Нэг Сүнстэй билээ. Тэд бүхэлдээ Миний төлөө зарлагадахад бэлэн байгаагаа сүнсээрээ мэдэрдэг. Иймээс Миний ууган хөвгүүдээс гадна хэн ч үнэн голоосоо, чин сэтгэлээсээ Миний хүсэлд санаа тавьдаггүй; Би Сатаныг байлдан дагуулсны дараа л тэд Надад үйлчлэл үзүүлэхийг хүсдэг.

Миний мэргэн ухаан, Миний ууган хөвгүүд бүгдээс дээр байж, бүгдийг ялдаг бөгөөд ямар ч юм, хүн, хэрэг явдал саад болж зүрхэлдэггүй. Түүнчлэн, ямар ч хүн,

хэрэг явдал, юмс тэднийг ялж чадахгүй, харин ч Миний үнэн биеийн өмнө бүгд дуулгавартай захирагддаг. Энэ бол нүдний өмнө тохиолддог баримт, мөн Миний хэдийнээ хэрэгжүүлсэн баримт юм. Дуулгаваргүй байсаар байгаа хэнийг ч (дуулгаваргүй нэгэн гэдэг нь мөн л Сатаныг хэлдэг ба Сатанд эзэмдүүлсэн хүмүүс нь маргаангүй Сатан юм) Би үндэс, мөчрөөр нь устгаж, хойшдын төвөг бэрхшээлийг арилгана; Миний гэсгээлтээс болж тэд даруй үхэх болно. Энэ төрлийн Сатан нь Надад үйлчлэл үзүүлэхийг хүсдэггүй. Бүтээлийн цагаас хойш эдгээр нь үргэлж Миний эсрэг зөрүүдлэн зогссон бөгөөд өнөөдөр ч гэсэн тэд Надад дуулгаваргүй байсаар байна. (Энэ нь ердөө сүнсний талаарх асуудал учраас хүмүүс үүнийг харж чадахгүй байна. Иймэрхүү хүн иймэрхүү төрлийн Сатаныг төлөөлдөг). Бусад бүх зүйл бэлэн болохоос өмнө Би эхлээд тэднийг устгаж, тэдэнд хүнд шийтгэлийн сахилгажуулалт үүрд өгнө. (Энд, “устгах” гэдэг нь “цаашид оршихгүй болгоно” гэсэн үг биш, харин тэдэнд хэр зэрэг хатуурхахыг хэлдэг. “Устгах” гэдэг үг нь энд устгагдах хүмүүс гэдэгт ашиглагддаг “устгах” гэдэг нэр томьёоноос ялгаатай юм.) Тэд эцэс төгсгөлгүйгээр, үүрдийн үүрд уйлж, шүдээ хавирна. Хүний төсөөлөл ийм дүр зургийг ургуулан бодох ямар ч чадваргүй. Хүн эгэл хүний сэтгэлгээгээр сүнслэг зүйлсийг ухан ойлгож чаддаггүй, тийм ч учраас Сион руу буцсаныхаа дараа л та нарын ойлгох илүү олон зүйл бий.

Миний ирээдүйн гэрт Миний ууган хөвгүүд болон Надаас өөр хэн ч байхгүй, зөвхөн тэр үед л Миний зорилго биелж, Миний төлөвлөгөө амжилттай хэрэгжих болно, учир нь бүгд анхны байдалдаа орж, бүгд өөр өөрсдийн төрлийн дагуу ангилагдах болно. Миний ууган хөвгүүд Надад харьяалагдаж, Миний хөвгүүд болон ардууд бүтээгдсэн зүйлсэд харьяалагдаж, үйлчлэл үзүүлэгчид болон устгагдсан хүмүүс Сатанд харьяалагдана. Би болон Миний ууган хөвгүүд дэлхийг шүүсний дараа дахин нэг удаа бурханлаг амьдралыг эхлүүлнэ, тэд Надаас хэзээ ч явахгүй, Надтай үргэлж хамт байх болно. Хүний оюун санаагаар ойлгож болох бүхий л нууц бага багаар та нарт илчлэгдэнэ. Түүхийн туршид, өөрсдийгөө Надад бүхэлд нь өргөн Надаас болж амиа зориулсан тоймгүй олон хүн байсан хэдий ч эцсийн эцэст хүмүүс бол бүтээгдсэн зүйл бөгөөд хэчнээн сайн байлаа ч тэднийг Бурхан гэж ангилж болохгүй; энэ бол үйл явдлын зайлшгүй голдирол, хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Эцсийн эцэст, Бурхан бол бүх зүйлийг бүтээгч, харин хүн бол бүтээгдсэн зүйл, Сатан бол эцсийн эцэст Миний устгалын бай, Миний үзэн яддаг дайсан—энэ нь “тэнгэрийн муухай арилдаг, хүний муухай арилдаггүй” гэдэг үгийн жинхэнэ утга юм. Одоо энэ нөхцөл байдалд болон энэ үе шатанд байна гэдэг нь Би болон Миний ууган хөвгүүд амрахын тэмдэг юм. Учир нь дэлхий дээрх Миний ажил бүхэлдээ дууссан ба Өөрийн ажлын дараагийн алхмыг гүйцээхийн тулд Би бодит биед буцаж орох шаардлагатай. Энэ бол аль эрт төлөвлөсөн Миний ажлын алхмууд билээ. Энэ асуудлыг тодорхой ойлгох ёстой, эс бөгөөс ихэнх хүн Миний захиргааны зарлигийг зөрчих болно.

115-Р БҮЛЭГ

Чамаас болж Миний зүрх сэтгэл асар их баярлан хөөрнө; чамаас болж Миний гар баяр хөөртэйгөөр бүжиж, Би чамд дуусашгүй их ерөөл өгнө, учир нь чи бүтээлийн цаг үеэс өмнө Надаас ирсэн. Өнөөдөр чи Миний дэргэд эргэж ирэх ёстой, учир нь чи дэлхий ертөнцийнх биш, газрынх биш, харин Минийх билээ. Би чамайг үүрд хайрлаж, чамайг үүрд ерөөж, чамайг үүрд хамгаална. Надаас ирсэн хүмүүс л Миний хүслийг мэддэг, зөвхөн тэд л Миний ачаанд санаа тавьж, Миний хүссэн зүйлийг хийнэ. Өнөөдөр, бүх зүйл гүйцэлджээ. Миний зүрх яг галт бөмбөг адил хайрт хөвгүүд минь удахгүй Надтай эргэж нийлэхийг, Миний үнэн бие Сион руу бүрмөсөн буцахыг хүсэмжилж байна. Чамд энэ талаар зарим нэг мэдлэг бий. Хэдийгээр бид сүнсээрээ байнга нэг нэгнээ дагаж чаддаггүй ч үргэлж нэг нэгэндээ сүнсээрээ бараа болж, бие махбодоороо уулздаг. Эцэг болон хөвгүүд үүрд салшгүй, дотно холбогдсон. Сион уул руу буцах өдрийг хүртэл хэн ч чамайг Миний дэргэдээс булаан авч чадахгүй. Надаас ирдэг бүх ууган хөвгүүдээ Би хайрлаж, Намайг эсэргүүцдэг бүх дайсныг Би үзэн яддаг. Би хайрладаг хүмүүсээ Сион руу аваачиж, үзэн яддаг хүмүүсээ Үхэгсдийн орон руу, там руу чулуудах болно. Энэ бол Миний бүх захиргааны зарлигийн гол зарчим юм. Миний ууган хөвгүүдийн хэлдэг хийдэг бүхэн Миний Сүнсний илэрхийлэл. Хүн бүр үүнийг тодорхой ойлгосон нөхцөлд Миний ууган хөвгүүдэд гэрчлэл хийх ёстой. Энэ нь Миний ажлын дараагийн алхам, хэрвээ хэн нэгэн эсэргүүцвэл, Би Өөрийн хайрт хөвгүүдээр тэднийг шийдвэрлүүлнэ. Одоо бол урьдынхаас ондоо. Хэрвээ Миний хайрладаг хүмүүс шүүлтийн үг хэлбэл Сатан Үхэгсдийн оронд тэр дороо үхэх болно, учир нь Би Өөрийн ууган хөвгүүдэд аль хэдийн эрх мэдэл өгчихсөн. Өөрөөр хэлбэл, одоогоос эхлээд Миний ууган хөвгүүд болон Би хамтдаа захирах цаг нь болсон. (Энэ нь биеэр захирахаас бага зэрэг ялгаатай, бие махбодын үе шатанд байгаа юм.) Бодлоороо дуулгаваргүй байдаг хэн боловч Миний үнэн биеийг эсэргүүцдэг хүмүүстэй адил хувь заяаг эдэлнэ. Миний ууган хөвгүүдэд Миний адилаар хандах ёстой, учир нь бид нэг биетэй бөгөөд хэзээ ч салж болохгүй. Өнгөрсөнд Намайг гэрчилсэнтэй адилаар өнөөдөр Миний ууган хөвгүүдийг гэрчлэх хэрэгтэй. Энэ бол Миний захиргааны зарлигийн нэг юм; хүн бүр босож, гэрчлэл хийх ёстой.

Миний хаанчлал газар дэлхийн зах хязгаар хүртэл тэлдэг, Миний ууган хөвгүүд Надтай хамт ертөнцийн зах хязгаар хүртэл аялдаг. Та нар махан биедээ чөдөрлөгддөг учраас Би хэлж өгсөн ч та нарт ойлгодоггүй олон үг байдаг, иймээс ихэнх ажлыг Намайг Сион руу буцсаны дараа хийж дуусгах ёстой. Ийнхүү буцаж очих нь холгүй байгааг, үнэндээ тэр мөч бараг ирснийг Миний үгээс харж болно. Тийм ч учраас Би Сион болон Сионы хэрэг явдлын талаар байнга ярьж байна. Та нар Миний үгийн зорилго юу болохыг мэдэх үү? Миний зүрх сэтгэлд юу байгааг мэдэх үү? Миний зүрх сэтгэл Сион руу буцан очиж, хуучин эрин үеийг бүхэлд нь төгсгөж, газар дээрх амьдралаа төгсгөж (учир нь Би хорвоогийн хүмүүс, хэрэг

явдал, юмсыг жигшиж, махан бие дэх амьдралыг бүр ч их үзэн яддаг, махан биеийн чөдөр тушаа үлэмж бөгөөд Сион руу буцсаны дараа л бүх зүйл хөгжин цэцэглэх болно), хаанчлал дахь амьдралаа сэргээхийг хүсэмжилдэг. Эхний удаад бие махбодтой болсны минь зорилго нь хоёр дахь удаа бие махбодтой болох суурийг тавихын төлөө байсан юм. Энэ бол аялах ёстой зам байлаа. Өөрийгөө бүхэлд нь Сатанд өгч байж л, Би та нарыг золин аварч чадах байсан, ингэснээр та нар эцсийн үе шатанд Миний бие рүү эргэн орж магад. (Эхний удаад бие махбодтой болоогүй бол Би алдрыг олж авч чадахгүй, нүглийн тахилыг буцааж авах боломжгүй байх байсан, иймд та нар дэлхий дээр нүгэлтэн болж ирэх байлаа.) Би хязгааргүй мэргэн ухаантай учраас та нарыг Сионоос хөтөлж гарсан баримт нь та нарыг гарцаагүй Сион руу буцаан авчрах болно гэсэн үг юм. Сатаны саад болох оролдлого бүтэмжтэй болохгүй, учир нь Миний агуу ажил аль эрт гүйцэлдчихсэн. Миний ууган хөвгүүд Миний адил ариун агаад өө сэвгүй учир Би ууган хөвгүүдийн хамт Сион руу буцна, бид хэзээ ч салахгүй.

Миний удирдлагын төлөвлөгөө бүхэлдээ та нарт аажмаар илчлэгддэг. Би бүх улс үндэстэн, бүх хүний дунд Өөрийн ажлыг хэрэгжүүлээд эхэлчихсэн. Миний Сион руу буцах цаг холгүй байгааг нотлоход энэ нь хангалттай, учир нь бүх улс үндэстэн, хүмүүсийн дунд Өөрийн ажлыг хэрэгжүүлэх нь Сион руу буцсаны дараа хийгдэх зүйл юм. Миний алхаа улам бүр түргэсэж байна. (Сион руу буцах өдөр минь ойртож байгаа учир буцахаасаа өмнө Би газар дээрх ажлаа дуусгахыг хүсэж байна.) Би ажилдаа улам бүр завгүй болж байгаа хэдий ч газар дээр Надад хийх ажил улам бага болж, бараг юу ч үлдсэнгүй. (Миний завгүй байдал Сүнсээр хийх ажилд чиглэдэг, үүнийг хүний энгийн нүдээр харж чадахгүй, харин зөвхөн Миний үгээс л мэдэж авч болно; Миний завгүй байдал махбодод завгүй байдаг шиг биш, харин олон ажил төлөвлөж байгааг минь хэлж байгаа юм.) Учир нь, Миний хэлсэнчлэн, газар дээрх Миний ажил аль хэдийн нэгд нэггүй гүйцэлдчихсэн бөгөөд Миний ажлын үлдсэн хэсэг Намайг Сион руу буцах хүртэл хүлээх ёстой. (Би ажиллахаар Сион руу буцах ёстойн шалтгаан нь ирээдүйн ажлыг махбодоор гүйцэлдүүлж болохгүй бөгөөд хэрвээ энэ ажлыг махбодоор хийвэл Миний нэрийг гутаах болно.) Би дайснуудаа ялж, Сион руу буцах үед амьдрал эрин үеүдээс өмнөх амьдралаас илүү сайхан, амар амгалан байх болно. (Яагаад гэвэл, Би дэлхий ертөнцийг бүхэлд нь ялсан, мөн эхний болон хоёр дахь удаагаа бие махбодтой болсныхоо ачаар Би алдрыг бүрэн олж авсан. Эхний удаа бие махбодтой болохдоо Би Өөрийн алдрын нэгээхэн хэсгийг олж авсан, харин хоёр дахь удаа бие махбодтой болоход Миний үнэн бие алдрыг бүрэн олж авсан бөгөөд Сатанд дарлан мөлжих ямар ч завшаан үлдээгүй. Иймээс, Сион дахь ирээдүйн амьдрал илүү сайхан, амар амгалан байх болно.) Агуу улаан лууг шившиглэхийн тулд Миний үнэн бие дэлхий ертөнц болон Сатаны өмнө улам илүү суу алдартайгаар гарч ирнэ; энэ бол Миний бүх мэргэн ухааны цөм юм. Би гадаад зүйлсийн талаар илүү их ярих тусам, та нар илүү их ойлгож чадна; Би хүмүүсийн харж чаддаггүй Сионы зүйлсийн талаар ярих тусам,

та нарт эдгээр зүйл улам хоосон санагдаж, тэдгээрийг төсөөлөхөд улам хэцүү болж, Намайг үлгэр ярьж байна гэж бодно. Гэхдээ, та нар сэрэмжтэй байх ёстой; Миний аманд хоосон үг байдаггүй, Миний амнаас гардаг үг найдвартай. Хэдийгээр та нарын сэтгэлгээгээр үүнийг ойлгоход хэцүү боловч энэ бол туйлын үнэн. (Махан биеийн хязгаарлалтаас болж хүн Миний хэлдэг зүйлийг бүхэлд нь нэгд нэгэнгүй ойлгож чаддаггүй, Би хэлсэн олон зүйлээ бүрэн дүүрэн илчлээгүй. Гэхдээ биднийг Сион руу буцах үед Би тайлбарлах хэрэггүй, та нар аяндаа ойлгоно.) Үүнд хайнга хандаж болохгүй.

Хэдийгээр хүний махан бие болон үзэл хязгаарлагдмал ч гэсэн Би илчилсэн нууцуудаараа дамжуулан махан биеийн сэтгэлгээг чинь сайжруулж, үзэлтэй чинь тэмцэлдэхийг хүсэж байна, учир нь Би олон удаа хэлж байсанчлан энэ бол Миний ажлын алхам (тэгээд Сион руу орох хүртэл энэ ажил зогсохгүй). Хүн бүрийн оюун санаанд Сион уул байдаг бөгөөд хүн бүрийн хувьд энэ нь өөр байдаг. Би Сион уулын талаар дурдсаар байгаа болохоор үүний талаар ерөнхий мэдээлэл та нарт өгье, ингэснээр та нар үүний талаар бага зэрэг мэддэг болно. Сион ууланд гарна гэдэг нь сүнсний ертөнц рүү буцах явдал юм. Хэдийгээр энэ нь сүнсний ертөнцийг хэлдэг боловч, хүмүүсийн харж, хүрч чаддаггүй газар биш; энэ нь биеийг хэлж байгаа юм. Бие гарч ирэх үедээ хэлбэр, дүрстэй байдаг боловч бие гарч ирээгүй байх үедээ хэлбэр, дүрсгүй байдаг учраас энэ нь огт харагддаггүй, биет бус зүйл биш билээ. Сион ууланд, хоол унд, хувцас хунар, өдөр тутмын хэрэгцээ, орогнох газрын талаар санаа зовох хэрэггүй, бас гэрлэлт, гэр бүл гэж байхгүй, хүйсийн ялгаа байхгүй (Сион ууланд байгаа бүхэн нэгэн биед байгаа Миний үнэн бие учраас ямар ч гэрлэлт, гэр бүл, хүйсийн ялгаа гэж байхгүй), Миний үнэн биеийн ярьдаг бүх зүйл биеллээ олно. Хүмүүсийг сэрэмжгүй байх үед Миний үнэн бие тэдний дунд гарч ирж, хүмүүс анхаарал хандуулаагүй байх үед Миний үнэн бие алга болно. (Мах цуснаас бүрддэг хүмүүс үүнийг биелүүлж чадахгүй, иймээс одоо та нар үүнийг төсөөлөхөд хэцүү.) Ирээдүйд, нар, сар, биет тэнгэр, газар байсаар байх боловч Миний үнэн бие Сионд байх учир нар шарахгүй, өдөр гэж байхгүй, байгалийн гамшигт зовохгүй. Бурхан бидэнд гэрэл өгөх учраас бидэнд дэнгийн гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй гэж Би хэлэхдээ Сионд байх тухайгаа ярьж байсан. Хүмүүсийн үзлээр бол орчлон ертөнц дэх бүх зүйл таягдан хаягдаж, бүх хүн Миний гэрэлд амьдрах ёстой. Энэ нь, “Бурхан бидэнд гэрэл өгөх учраас бидэнд дэнгийн гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй” гэдгийн жинхэнэ утга учир гэж тэд боддог, гэвч үнэндээ энэ бол буруу тайлбар юм. Би “сар болгон, мод арван хоёр төрлийн жимс ургуулна” гэж хэлэхдээ Сион дахь хэрэг явдлыг хэлж байсан билээ. Энэ өгүүлбэр нь Сион дахь амьдралын нөхцөлийг бүхэлд нь төлөөлдөг. Сионд цаг хугацааны хязгаар гэж байхгүй, бас газар зүй, орон зайн хязгаар ч гэж байхгүй. Ийм учраас Би “сар болгон” гэж хэлсэн. “Арван хоёр төрлийн жимс” нь Сион дахь эрх чөлөөтэй амьдралыг хэлж байгаа болохоос өнөөдөр та нарын амьдран харуулж байгаа зан авирыг төлөөлдөггүй. Эдгээр үг нь Сион дахь амьдралыг ерөнхийд нь хэлсэн юм. Үүнээс

Сион дахь амьдрал элбэг баян агаад олон янз байдаг гэдгийг харж болно (учир нь “арван хоёр” гэдэг нь энд элбэг дэлбэг байдлыг хэлдэг). Гашуудал болоод нулимсгүй амьдрал байх болно, мөлжлөг, дарангуйлал ч байхгүй учраас бүх зүйл чөлөөлөгдсөн, эрх чөлөөтэй байна. Яагаад гэвэл бүх зүйл Миний үнэн бие дотор оршиж, ямар ч хүн салгаж чадахгүй бөгөөд бүх зүйл гоо үзэсгэлэн, үүрдийн шинэхэн байдлын дүр зураг байх болно. Тэр үе нь бүх зүйл бэлэн болсон цаг, Сион руу буцсаны маань дараах амьдралын эхлэл байх болно.

Хэдийгээр газар дээрх Миний ажил бүрэн дүүрэн гүйцэлдсэн ч гэсэн Миний ууган хөвгүүд газар дээр ажиллах нь Надад хэрэгтэй байсаар л байна, иймээс Би хараахан Сион руу буцаж болохгүй. Би Сион руу ганцаараа буцаж болохгүй, Миний ууган хөвгүүд газар дээрх ажлаа дуусгасны дараа бид Сион руу хамтдаа буцна. Тиймээс хамтдаа алдрыг олж авч байна гэж хэлэх нь зүйтэй болов уу; энэ бол Миний үнэн биеийн бүрэн илрэл билээ. (Миний ууган хөвгүүд хараахан илрээгүй учраас газар дээрх Миний ууган хөвгүүдийн ажил хараахан дуусаагүй гэж Би хэлдэг. Энэ ажлыг үнэнч агаад шударга үйлчлэл үзүүлэгчид хийсээр байх ёстой.)

116-Р БҮЛЭГ

Миний үгэн дунд хүмүүсийг айлгадаг үг олон бий. Миний олон үг хүмүүсийг айн чичрэхэд хүргэдэг, Миний олон үг хүмүүсийг зовоож, итгэл найдварыг нь алдуулж, бүр ч олон үг нь хүмүүсийг сүйрүүлдэг. Миний үгийн баялаг байдлыг хэн ч тодорхой ойлгож, ухаарч чадахгүй. Би та нарт үгээ өгүүлбэр бүрээр нь хэлж, илчлэх үед л та нар ерөнхий байдлыг мэдэж чаддаг, харин тодорхой баримтуудын үнэн мөнийг ойлгохгүй хэвээр үлддэг. Иймээс Би та нарт илүү их ойлгуулахын тулд Өөрийн бүх үгийг илчлэхдээ баримт ашиглана. Миний ярианы хэв маягийг харвал, Би үгээ хэлээд зогсохгүй, харин ч бүр үгээрээ үйлдэж байна; энэ нь “үг болон бодит байдал зэрэгцэн явагдаж буйн” жинхэнэ утга юм. Учир нь Миний хувьд юм бүхэн эрх чөлөөтэй, юм бүхэн чөлөөлөгдсөн байдаг бөгөөд энэхүү суурин дээр Миний хийдэг бүхэн мэргэн ухаанаар дүүрэн байдаг. Би дураараа ярьдаггүй, бас дураараа үйлддэггүй. (Хүн чанарт ч бай, бурханлаг чанарт ч бай, Би мэргэн ухаанаар үг хэлж, үйлддэг, учир нь Миний хүн чанар бол Миний салшгүй хэсэг юм.) Гэвч Намайг ярихад ярианы минь өнгөнд хэн ч анхаарал хандуулдаггүй; Намайг үйлдэхэд ажлын минь арга барилд хэн ч анхаарал тавьдаггүй. Энэ бол хүний дутагдал юм. Би хүч чадлаа бүх хүн дээр илчилнэ, ууган хөвгүүд дээрээ төдийгүй, цаашлаад бүх улс үндэстэн, бүх ард түмний дотор илчилнэ; ингэх нь л Сатаныг шившиглэх хүчирхэг гэрчлэл юм. Би тэнэг юм хийдэггүй. Би ууган хөвгүүдээ гэрчилдэг нь алдаа гэж олон хүн боддог; тэд Надаас гадна өөр Бурхад бий гэдэг, бас Намайг ухаангүй авирлаж, Өөрийгөө доош хийж байна гэцгээдэг; эндээс хүний завхрал бүр ч их илчлэгддэг. Ууган хөвгүүдэд гэрчлэл хийх нь Миний алдаа юм гэж үү? Та нар

Намайг бурyутай гэдэг, тэгвэл та нар гэрчилж чадах уу? Хэрэв Миний өргөлт, Миний гэрчлэл байгаагүй сэн бол та нар бас л Миний Хүүг дороо дэвсэлж, Түүнтэй хүйтэн хөндий байдлаар харьцаж, зарц чинь мэт хандах байсан. Гахайн сүрэг! Хариуд нь Би та нарыг нэг нэгээр чинь хаяна! Хэнийг ч зүгээр өнгөрүүлэхгүй! Надад хэл дээ, хэвийн хүн чанартай хүнтэй нийцдэггүй тэр юмнууд юу вэ? Гахай гэдэг нь эргэлзээгүй! Би тэднийг ерөөсөө л харж тэвчдэггүй. Та нарын гэрчлэлийг хүлээсэн бол Миний ажил аль хэдийн саатсан байх байлаа! Энэ гахайн сүргийг дээ! Та нарт ердөөсөө л хүн чанар гэж огт алга! Чамаар Өөртөө үйлчлэл хийлгэх хэрэг Надад байхгүй! Эндээс яг одоо яв! Чи Миний Хүүг маш удаан хугацаанд дээрэлхэж, дарлалаа; Би чамайг няц гишгэнэ! Чи зүгээр л дахиад зэрлэг байх гээд үз; чи зүгээр л Намайг дахиад шившиглэх гээд үз! Би агуу ажлаа аль хэдийн гүйцэлдүүлсэн; Би энэ арааТны сүргийг хөөн явуулж, хаях учиртай!

Миний гарт бүгд биелж (Миний хайрладаг хүмүүсийн хувьд), бас Миний гарт бүгд устгагддаг (Миний үзэн яддаг тэр арааТнууд, Миний жигшдэг тэр хүмүүс, үйл явдал болон зүйлсийн хувьд). Би Өөрийн хийх юм бүхнийг ууган хөвгүүддээ харуулж, бүрэн ойлгуулж, улмаар Сионоос гарснаасаа хойш Өөрийн хийсэн бүхнийг харуулна. Дараа нь бид Сион уул руу хамт орж, эрин үеүдийн өмнө өөрсдийнхөө байсан газарт орж, шинээр амьдарна. Тэр үеэс эхлээд дэлхий болон энэ гахайн сүрэгтэй дахин хэзээ ч холбоо тогтоохгүй, харин бүрэн эрх чөлөөтэй байна; бүгд саадгүй, төвөггүй урагшилна. Хэн ууган хөвгүүдийн минь нэгийг эсэргүүцэж зүрхлэх вэ? Хэн Миний ууган хөвгүүдийг үргэлжлүүлэн сөрж зүрхлэх вэ? Би түүнийг амархан өршөөхгүй! Намайг өмнө нь хүндэлсэн шигээ өнөөдөр ууган хөвгүүдийг минь тэгж хүндлэх ёстой. Миний өмнө нэг өөр, ар хударгаар минь нэг өөр байж болохгүй; Би хүн бүрийг тов тодорхой хардаг. Миний Хүүд үнэнч бус байна гэдэг Надад ачлалгүй байна гэсэн үг, энэ бол илэрхий баримт, учир нь Бид нэгэн бие юм. Хэрэв хүн Надад сайн атлаа ууган хөвгүүдэд минь өөр хандлага баримталдаг бол тэрээр Христийн биеийг хувааж буй учир агуу улаан лууны үр удам гэдэг нь эргэлзээгүй; энэ нүглийг хэзээ ч өршөөж болохгүй! Үүнийг хүн бүр харах ёстой. Намайг гэрчлэх нь та нарын үүрэг, ууган хөвгүүдийг гэрчлэх нь бүр ч та нарын даалгавар юм. Хэн чинь ч хариуцлагаасаа булТах учиргүй; саад хийсэн хэнийг ч бай Би тэр дор нь хаяна! Өөрийгөө гойд сайн гэж бүү бод. Би чамд хэлье: Ийм байх тусмаа хамгийн хатуу шийтгэлийн минь бай болно! Ийм байх тусмаа найдвар чинь улам бүр тасарч, улам бүр мөхлийн хүү болно. Би чамайг үүрд гэсгээнэ!

Миний бүх ажлыг Миний Сүнс биечлэн хийдэг бөгөөд төлөвлөгөөг минь сүйтгэхээс зайлсхийхийн тулд Би Сатаны төрлийн хэнд ч хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрдөггүй. Эцэст нь Би хүүхдүүд болон насанд хүрэгчдийн аль алинд өндийн босож, Намайг болон ууган хөвгүүдийг минь магтаж, гайхамшигт үйл хэргийг минь магтаж, Миний үнэн биеийн илрэлийг магтах боломж олгоно. Би магтаалын дууг бүхий л орчлон ертөнц, газар дэлхийн зах хязгаар хүртэл цуурайтуулж, уул нурууд, гол мөрөн, бүх зүйлийг доргиож, Сатаныг бүрэн шившиглэнэ. Би Өөрийн

гэрчлэлийг ашиглан бузар, булай хуучин дэлхийг бүхэлд нь устгаж, ариун, бузартаагүй шинэ дэлхийг байгуулна. (Нар, сар, одод, огторгуйн эрхэс ирээдүйд өөрчлөгдөхгүй гэж хэлсэн минь хуучин дэлхий оршсоор байна гэсэн үг биш, харин ч бүхий л дэлхий устгагдаж, хуучин дэлхий солигдоно гэсэн үг юм. Би орчлон ертөнцийг солино гээгүй.) Зөвхөн тэр л үед энэ нь Миний хүсэлд нийцсэн дэлхий байх болно; тэнд өнөөгийнх шиг дарлал гэж байхгүй, мөн хүмүүс нэг нэгнээ шулан мөлжих явдал байхгүй байх болно. Харин ч махан биеийн дотор бүрэн дүүрэн шударга ёс, үндэслэлтэй байдал л байна. (Хэдийгээр Би тэнд шударга ёс, үндэслэлтэй байдал байна гэж хэлдэг ч энэ нь махан биеийн дотор байх болно; Миний хаанчлалтай харьцуулахад энэ нь тэнгэр, газар мэт тун их ялгаатай; энэ хоёрыг үнэхээр харьцуулахын аргагүй—эцсийн эцэст, хүний ертөнц бол хүний ертөнц, сүнсний ертөнц бол сүнсний ертөнц юм.) Тэр үед Би ууган хөвгүүдийнхээ хамт ийм дэлхийг захирна (Сатаныг Би бүрэн хаясан байх учир энэ дэлхийд Сатаны хөндлөнгийн оролцоо гэж байхгүй байна), гэвч бидний амьдрал хаанчлалын амьдрал хэвээр байна, үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Эрин үеүдийн туршид Миний ууган хөвгүүн болох нэг ч хүн байгаагүй учир эрин үеүдийн туршид ямар ч хүн (хэчнээн ч үнэнч байлаа гэсэн) энэ төрлийн амьдралыг хэзээ ч туулаагүй бөгөөд дараа нь тэд мөн л Надад үйлчлэл үзүүлнэ. Хэдийгээр энэ үйлчлэл үзүүлэгчид үнэнч боловч эцсийн эцэст Миний байлдан дагуулсан Сатаны үр удам учир махан биеийн үхлийн дараа тэд бас л Надад үйлчлэл үзүүлэхээр хүний дэлхийд төрдөг; “хөвгүүд бол эцсийн эцэст хөвгүүд, үйлчлэл үзүүлэгчид бол эцсийн эцэст Сатаны үр удам” гэдгийн жинхэнэ утга учир энэ юм. Эрин үеүдийн туршид хэчнээн олон хүн өнөөдрийн ууган хөвгүүдийн төлөө үйлчлэл үзүүлснийг бүү мэд; бүх үйлчлэл үзүүлэгчийн хэн нь ч зугтаж чадахгүй бөгөөд Би тэднээр Өөртөө үүрд үйлчлэл хийлгэнэ. Тэдний уг чанарыг авч үзвэл бүгд Сатаны хүүхдүүд бөгөөд бүгд Намайг эсэргүүцдэг, хэдий тэд Надад үйлчлэл үзүүлдэг ч албан хүчээр л хийдэг ба өөр сонголт тэдэнд байдаггүй. Яагаад гэвэл, Миний гар бүх зүйлийг хянадаг, Миний ашигладаг үйлчлэл үзүүлэгчид эцсээ хүртэл Надад үйлчлэл үзүүлэх ёстой. Тиймээс, эрин үеүдийн турш дахь эш үзүүлэгчид, элч нартай адил шинж чанартай хүмүүс өнөөдөр ч олон байдаг, учир нь тэд нэг сүнстэй юм. Иймд, Миний төлөө гүйдэг үнэнч үйлчлэл үзүүлэгч олон хэвээр боловч эцэстээ (зургаан мянган жилийн турш Надад үйлчлэл үзүүлсээр ирсэн тул энэ хүмүүс үйлчлэл үзүүлэгчдэд харьяалагдана) эрин үеүдийн туршид тэр бүх хүний найдаж ирсэн зүйлийг хэн ч олж авч чадахгүй, учир нь Миний бэлдсэн зүйл тэдэнд зориулагдаагүй.

Миний бүх зүйл аль хэдийн нүдний өмнө биелсэн; Би ууган хөвгүүдээ Өөрийн гэрт буцаан ирүүлж, Өөрийн хажууд эргүүлэн авчирч, нэг дор цуглуулна. Би амжилттайгаар, ялгууснаар эргэн ирж, алдар сууг бүрэн олж авсан учир та нарыг буцаан аваачихаар ирсэн. Өмнө нь зарим хүн “ухаалаг таван охин, мунхаг таван охины” тухай таамагласан; хэдийгээр энэ таамаглал үнэн зөв биш боловч бас тэр чигтээ буруу биш, тиймээс Би та нарт зарим нэг тайлбар өгч болно. “Ухаалаг таван

охин болон мунхаг таван охин” нь хамтдаа хүмүүсийн тоог ч, нэг төрлийн хүнийг ч төлөөлдөггүй. “Ухаалаг таван охин” гэдэг нь олон тооны хүнийг хэлж, “мунхаг таван охин” нь нэг төрлийн хүнийг төлөөлдөг, гэхдээ энэ хоёрын аль нь ч ууган хөвгүүдийг хэлдэггүй. Харин тэд бүтээлийг төлөөлдөг. Эцсийн өдрүүдэд тос бэлтгэхийг тэднээс хүссэн нь ийм учиртай юм. (Бүтээлд Миний чанар байдаггүй; хэрэв тэд ухаалаг хүмүүс байхыг хүсвэл тос бэлтгэх хэрэгтэй, тиймээс тэд Миний үгээр зэвсэглэсэн байх хэрэгтэй.) “Ухаалаг таван охин” нь Миний бүтээсэн хүмүүсийн дундах Миний хөвгүүд, Миний ардуудыг төлөөлдөг. Газар дээр төрсөн мөртөө Надаар авхуулдаг учраас тэднийг “охид” гэж нэрлэдэг; тэднийг ариун гэж дуудаж болох тул “охид” гэж нэрлэдэг. Дээр дурдсан “тав” гэдэг нь Миний урьдчилан тогтоосон хөвгүүд, ардуудын тоог төлөөлдөг. “Мунхаг таван охин” нь үйлчлэл үзүүлэгчдийг хэлдэг. Тэд аминд өчүүхэн төдий ч ач холбогдол өгөлгүй, зөвхөн гадаад зүйлсийг хөөцөлдөн Надад үйлчлэл үзүүлдэг (тэдэнд Миний чанар байхгүй учир юу ч хийсэн бай, тэр нь гадаад зүйл байдаг), бас тэд Миний чадварлаг туслагчид байж чаддаггүй учир “мунхаг охид” гэгддэг. Дээр дурдсан “тав” нь Сатаныг төлөөлдөг бөгөөд тэднийг “охид” гэж дууддаг нь Надаар байлдан дагуулагдсан, Миний төлөө үйлчлэл үзүүлж чадна гэсэн утгатай—гэвч ийм хүмүүс ариун биш тул үйлчлэл үзүүлэгч гэж нэрлэдэг.

117-Р БҮЛЭГ

Та бол хуйлмал номыг нээдэг Нэгэн, Та бол долоон лацыг эвддэг Нэгэн юм, учир нь Танаас бүх нууц ирж, Та бүх ерөөлийг илчилдэг. Би Таныг мөнхөд хайрлах үүрэгтэй ба бүх хүнд Таныг шүтүүлэх үүрэгтэй, учир нь Та бол Миний үнэн бие; Та бол Миний элбэг бөгөөд бүрэн төгс илрэлийн нэг хэсэг, Миний биеийн зайлшгүй шаардлагатай хэсэг юм. Иймээс, Би тусгай гэрчлэл хийх ёстой. Миний үнэн бие дотор байгаа Нэгнээс өөр хэн Миний зүрх сэтгэлийн дагуу байдаг вэ? Та Өөрөө Өөртөө гэрчлэл хийдэг биш, харин Миний Сүнс Таны төлөө гэрчлэл хийдэг бөгөөд Таныг эсэргүүцэж зүрхэлдэг хэнийг ч Би мэдээжийн хэрэг өршөөхгүй, учир нь энэ нь Миний захиргааны зарлигт хамаардаг. Таны хэлдэг бүхнийг Би маргаангүй биелүүлэх бөгөөд мөн Таны боддог бүхнийг Би заавал хүлээн зөвшөөрөх болно. Хэрвээ хэн нэгэн Танд үнэнч биш бол тэд Намайг илт эсэргүүцэж байгаа хэрэг бөгөөд Би тэднийг огтоос өршөөхгүй. Миний хөвгүүдийг эсэргүүцдэг бүгдийг Би хатуу гэсгээж, Тантай нийцтэй байдаг хүмүүсийг Би ерөөнө. Энэ бол Миний Танд олгодог эрх мэдэл юм. Урьд нь ярьж байсан, ууган хөвгүүдэд тавьсан шаардлага болон стандартын үлгэр дуурайл Та билээ. Өөрөөр хэлбэл, Та ямар байна, тийм байхыг Би ууган хөвгүүдээс шаардах болно. Энэ нь хүмүүсийн хийж чадах зүйл биш, харин Миний Сүнс Өөрөө хийдэг зүйл билээ. Хүмүүс Танд гэрчлэл хийдэг гэж хэн нэгэн хэрвээ итгэвэл тэрхүү бүтээл нь яахын аргагүй Сатаны төрөл, Миний дайсан мөн!

Ийм учраас, гэрчлэл бол шийдвэрлэх чухал, үүрд хувиршгүй бөгөөд Ариун Сүнсний баталдаг зүйл юм! Үүнийг хэн ч үл ялиг өөрчилж болохгүй, тэгсэн хэнийг ч бай Би өршөөхгүй! Хүмүүс надад гэрчлэл хийж чадахгүйгээс хойш, Би Өөрөө Өөрийнхөө үнэн биед гэрчлэл хийдэг бөгөөд хүмүүс Миний ажилд хөндлөнгөөс оролцох ёсгүй! Энэ бол хүн нэг бүрийн санаж явах ёстой хатуу шүүлтийн үг юм!

Та нар Миний хэлж байгаа зүйлийн бүх нарийн ширийнийг тунгаан бодож, анхааран үзэх хэрэгтэй. Миний үгэнд хааш яаш бүү ханд, харин анхааралтай сонс. Ууган хөвгүүд бол Миний үнэн бие, Миний хаанчлалын зайлшгүй хэсэг гэж Би яагаад хэлдэг вэ? Бүх эрин үеийн өмнө бид хамтдаа амьдарч байсан, хэзээ ч салж байгаагүй. Сатан үймүүлснээс болж, Би анх удаа бие махбодтой болсныхоо дараа Сион руу буцсан. Үүний дараа бид бүгдээрээ дэлхийд ирсэн бөгөөд эцсийн өдрүүдэд ялалт байгуулсныхаа дараа—өөрөөр хэлбэл, Сатаны ялзруулсан махан биеэс та нарыг дахин олж авсныхаа дараа Би та нарыг Сион руу буцаан аваачна, тэгж байж Миний үнэн бие хэзээ ч салахгүйгээр дахин нэгддэг. Үүний дараа Би дахин бие махбодтой болохгүй ба та нар ч Миний биеэс гарч ирэхгүй нь лавтай. Өөрөөр хэлбэл, үүний дараа Би дэлхийг дахин бүтээхгүй, харин ч Сионд Өөрийн хөвгүүдээс үүрд салахгүй хэвээр үлдэх болно, учир нь бүх зүйл одоо нэгд нэггүй гүйцэлдсэн бөгөөд Би бүхий л хуучин эрин үеийг төгсгөх гэж байна. Миний үнэн бие Сионд оршин байдаг учраас Сионд л шинэ тэнгэр болон газрын амьдрал бий. Үүнээс тусдаа орших шинэ тэнгэр, шинэ газар гэж байхаа болино. Миний үнэн бие Сионыг бүхэлд нь дүүргэдэг учир Би бол шинэ тэнгэр, Би бас шинэ газар. Миний ууган хөвгүүд бол шинэ тэнгэр, Миний ууган хөвгүүд бол шинэ газар гэж ч бас хэлж болно. Миний ууган хөвгүүд болон Би нэг биетэй, салшгүй юм. Миний талаар ярих нь зайлшгүй Миний ууган хөвгүүдийг оролцуулдаг бөгөөд биднийг салгах гэж оролдсон хэнийг ч Би огт өршөөхгүй. Би бүх улс үндэстэн болон хүмүүсийг Өөрийн сэнтийн өмнө буцаан ирүүлэхэд бүх Сатан нэгд нэгэнгүй шившиг болж, бүх бузар чөтгөр Надаас холдоно. Дараа нь зөвт байдал бүх хүний дунд (Миний хөвгүүд болон ардуудын дунд гэсэн үг) оршино гэдэг нь тодорхой, мөн бүх улс үндэстний дунд Сатаны ямар ч үймээн самуун байхгүй байна гэдэг нь ойлгомжтой юм, учир нь Би бүх улс үндэстнийг болон хүмүүсийг захирч байх болно, Би бүхий л орчлон ертөнцийг эзэмшиж байх бөгөөд бүх Сатан нэгд нэггүй сүйдэж, бүхэлдээ ялагдаж, Миний захиргааны зарлигийн шийтгэлийг хүлээж авна.

Би бүх хүний дунд ажлаа өрнүүлж байгаа хэдий ч тэдэнд Миний Сүнсний гэгээрэл л байдаг ба тэдний дундаас Миний нууцуудыг илчилж, Миний илэрхийлэл болох эрхтэй хүн нэг ч байхгүй. Надаас ирдэг Нэгэн л Миний ажлыг хийх чадвартай ба үлдсэнийх нь тухайд бол Би тэднийг түр зуур л ашигладаг. Миний Сүнс хүн дээр дур зоргоороо буудаггүй, учир нь Миний дотор байгаа бүх зүйл үнэ цэнтэй. Миний Сүнс хүн дээр буух болон Миний Сүнс хүн дээр ажиллах гэдэг нь шал өөр зүйлс юм. Миний Сүнс Миний гадна байдаг Нэгэн дээр ажилладаг, харин Миний Сүнс Надаас ирсэн хүн дээр буудаг. Энэ хоёр бол ямар ч холбоогүй асуудал юм. Учир нь Надаас

ирсэн Нэгэн бол ариун, харин Миний гадна байдаг хүмүүс хэчнээн сайн байлаа ч, ариун биш. Миний Сүнс ялихгүй шалтгаанаар хэн нэгэн дээр амархан буухгүй. Хүмүүс санаа зовох хэрэггүй. Би ямар ч алдаа гаргадаггүй бөгөөд Өөрийн хийдэг зүйлдээ зуун хувь итгэлтэй байдаг! Би Түүнийг гэрчилсэн учир Түүнийг заавал хамгаална; тэр Нэгэн гарцаагүй Надаас ирдэг бөгөөд Миний үнэн биед зайлшгүй шаардлагатай. Иймээс, хүмүүс өөрсдийн үзлийг хойш тавьж, Сатаны өгсөн аливаа санааг орхиж, Миний бүх айлдварыг үнэн гэдэгт итгэж, оюун санаандаа эргэлзэхгүй байгаасай гэж Би найддаг. Энэ бол хүмүүст өгч буй Миний даалгавар, Миний сануулга. Хүн бүр эдгээр зүйлийг мөрдөх ёстой, хүн бүр тэдгээрт чин сэтгэлээсээ дуулгавартай байх ёстой, хүн бүр Миний хэлдэг зүйлийг стандарт гэж авч үзэх ёстой.

Би зөвхөн бүх улс үндэстэн болон хүмүүсийн дунд Өөрийн ажлыг эхлэх гээгүй, харин Өөрийн ажлыг орчлон ертөнцийн хаа сайгүй эхлүүлэх гэж байгаа бөгөөд Миний Сион руу буцах өдөр холгүй байгааг энэ нь бүр ч их харуулдаг (учир нь Би бүх хүний дунд болон орчлон ертөнц даяар ажлаа эхлүүлэхээс өмнө Сион руу буцах шаардлагатай). Миний ажлын алхмуудыг болон Миний ажилладаг арга барилыг ухан ойлгож чадах хүн байна уу? Би харийнхантай сүнсэндээ уулзах болно гэж хэлдгийн шалтгаан нь үндсэндээ үүнийг махбодоор хийх боломжгүй бөгөөд Би хоёр дахь удаагаа эрсдэл хүлээхийг хүсэхгүй байгаа юм. Харийнхантай сүнсээр ярилцахын шалтгаан нь энэ. Энэ нь махан биеэр амьдарч буй хүмүүсийн төсөөлдөг[a] ямар нэгэн тодорхойгүй сүнсний ертөнц биш, харин жинхэнэ сүнсний ертөнцөд байх явдал юм. Би өөр эрин үед ярьж байх тул тухайн үед Миний хэлдэг зүйл ердөө ярих байдлаараа л өөр байх болно. Тийм учраас, Миний ярьдаг арга барилыг анзаарахыг Би хүмүүст ахин дахин сануулж байгаа бөгөөд Миний хэлдэг зүйлд хүмүүсийн дэлгэж чаддаггүй нууцууд байдаг гэдгийг ч бас сануулдаг. Гэхдээ Би яагаад эдгээр зүйлийг хэлдгийг хэн ч ойлгодоггүй бөгөөд Намайг өнөөдөр үүнийг хэлсэн учраас л бага зэрэг ойлгож чаддаг боловч бас л бүхэлд нь ойлгодоггүй. Өөрийн ажлын энэ үе шатны дараа Би та нарт алхам алхмаар мэдэгдэх болно. (Үүгээр дамжуулан Би зарим хүнийг таягдан хаяхыг хүссээр байгаа учир одоохондоо юу ч хэлэхгүй.) Миний ажлын дараагийн алхмын арга барил нь энэ. Би бол ухаалаг Бурхан Өөрөө гэдгийг хүн болгон анзаарч, тодорхой харах хэрэгтэй.

118-Р БҮЛЭГ

Миний Хүүд гэрчлэл хийхээр өндийн босдог хэнд ч болов Би нигүүлслээ хайрлана; Миний Хүүд гэрчлэл хийхээр өндийн босдоггүй, харин ч эсэргүүцэж, үнэлэлт дүгнэлтээ хийхдээ хүний үзэл ашигладаг хэнийг ч байсан Би устгана. Бүгд тодорхой харах ёстой! Миний Хүүд гэрчлэл хийж байгаа нь Намайг хүндэтгэж

[a] Эх бичвэрт “хүмүүсийн төсөөлдөг” гэх хэллэг байдаггүй.

байгаа үйлдэл бөгөөд энэ нь Миний хүслийг хангадаг. Эцгийг л хүндлээд, харин Хүүг нь дээрэлхэж, дарангуйлахаа боль. Ингэдэг хүмүүс бол агуу улаан лууны үр сад юм. Ийм өөдгүй амьтдаар Өөрийн Хүүд гэрчлэл хийлгэх хэрэг Надад байхгүй; Би тэднийг ёроолгүй нүхэнд устгана. Үнэнч, шударга үйлчлэл үзүүлэгчид Хүүд минь үйлчлэл үзүүлээсэй гэж Би хүсэж байна; бусад нь Надад хэрэггүй. Энэ бол Миний зөвт зан чанар бөгөөд Би бол ариун агаад өө сэвгүй Бурхан Өөрөө гэдгийг энэ нь харуулдаг. Миний захиргааны зарлигийг зөрчдөг хэнийг ч Би өршөөхгүй. Өнгөрсөнд, гэр бүл дотор ч бай, дэлхий дээр ч бай, Таныг үл тоомсорлож, хяхан хавчсан хэнийг ч Би нэг нэгээр нь гэсгээх бөгөөд хэнийг ч хэлтрүүлэхгүй, учир нь Надад мах, цуснаас бүрдсэн ямар ч хэсэг байхгүй. Өнөөдөр Танд гэрчлэл хийж байгаа нь тэдгээр үйлчлэл үзүүлэгч Надад үйлчлэл үзүүлээд дууссаныг харуулдаг, иймд бүү эргэлзэж, санаа зов. Эцсийн эцэст тэд бол Таны үйлчлэл үзүүлэгчид бөгөөд энэ бүхний эцэст Та бол тэнгэрийнх, Миний бие Тангүйгээр байж чадахгүй учир Та эцэст нь Миний биед эргэн ирнэ. Өмнө нь Таныг үл тоомсорлож, Тантай нийцдэггүй байсан хүмүүс (энэ нь бусдын харж чаддаггүй, харин зөвхөн Та л зүрх сэтгэлдээ мэддэг зүйл юм) одоо үнэн дүр төрхөө илчилж, унасан, учир нь Та бол Бурхан Өөрөө бөгөөд Таныг үл тоомсорлож, Танд халддаг хэнийг ч Та тэвчдэггүй. Хэдий үүнийг гаднаас нь огт харж болохгүй ч Миний Сүнс Таны дотор байгаа нь маргаангүй. Бүх хүн үүнд итгэх ёстой, эс бөгөөс Намайг үл тоомсорлодог бүх хүнийг Миний төмөр саваа цохих вий! Нэгэнт Би Танд гэрчлэл хийж байгаа хойно, Та гарцаагүй эрх мэдэлтэй бөгөөд Таны хэлдэг бүхэн бол Миний илэрхийлэл, Таны хийдэг бүхэн бол Миний илрэл, учир нь Та бол Миний хайрт, Та бол Миний үнэн биеийн дутагдаж болшгүй хэсэг билээ. Иймд Таны үйлдэл болгон, Таны өмсөж байгаа, Таны хэрэглэж байгаа зүйл, Таны амьдардаг газар—тэдгээр нь мөн гарцаагүй Миний үйл хэрэг юм. Хэн ч Танаас өө сэв олохыг оролдож, Таныг өөнтөглөх ёсгүй. Ингэсэн хүнийг Би өршөөхгүй!

Би бүх муу зарцыг гэрээсээ хөөж гаргаад, Өөрийн гэрт бүх үнэнч зарцаар ууган хөвгүүддээ гэрчлэл хийлгэнэ; энэ бол Миний төлөвлөгөө, Миний ажилладаг арга зам. Муу зарц нар Миний Хүүд гэрчлэл хийх үед үхсэн хүний үнэр үнэртэж, Надад жигшмээр байдаг. Үнэнч зарц нар Миний Хүүд гэрчлэл хийхэд, үнэнч, чин сэтгэлийнх байдаг бөгөөд Би үүнийг хүлээн зөвшөөрдөг. Иймээс, Миний Хүүд гэрчлэл хийхийг хүсдэггүй хэн боловч, яг одоо эндээс зайл! Би чамайг хүчлэхгүй—хэрвээ Би чамайг яваач гэвэл чи явах ёстой! Үр дагавар чинь юу болохыг, чамайг юу хүлээж байгааг хар; үйлчлэл үзүүлдэг хүмүүс үүнийг хэнээс ч илүү ойлгодог. Намайг үл тоомсорлодог хэнд ч Миний шүүлт, Миний уур, Миний хараал, Миний шатаалт, Миний дүрэлзсэн хилэн хэдийд ч тусна. Миний гар хэнд ч өршөөл үзүүлдэггүй; үйлчлэл үзүүлдэг хүн өмнө нь хэчнээн үнэнч байсан нь хамаагүй, өнөөдөр Миний Хүүг үл тоомсорлох аваас Би тэднийг даруй устгаж, Өөрийн өмнө үлдэхийг зөвшөөрөхгүй. Миний өршөөлгүй гарыг үүнээс харж болно. Хүмүүс Намайг мэддэггүй, тэдний уг чанар Намайг үл тоомсорлодог учраас Надад үнэнч

хүмүүс ч гэсэн өөрсдийн таашаалын төлөө л үнэнч байдаг. Өөрсдөд нь сөргөөр нөлөөлөх ямар нэгэн зүйл тохиолдвол тэдний зүрх сэтгэл тэр дороо өөрчлөгдөж, Миний дэргэдээс ухарч холдохыг хүсдэг. Энэ бол Сатаны уг чанар юм. Та нар өөрсдийгөө үнэнч хэмээн итгээд, өөрийнхөөрөө зүтгэх ёсгүй! Хэрэв өөрсдөд нь ашигтай зүйл байхгүй л бол энэ араатны сүрэг Надад үнэнч байж чадахгүй билээ. Хэрвээ Би Өөрийн захиргааны зарлигийг зарлаагүй бол та нар аль эрт ухарч няцах байсан. Та нар одоо бүгд хадны завсар хавчуулагдсан, Надад үйлчлэл үзүүлэхийг хүсдэггүй мөртөө Миний гарт цохиулахыг бас хүсдэггүй. Намайг үл тоомсорлодог хэнд ч хэдийд ч үлэмж гай гамшиг тохиолдоно гэж Намайг тунхаглаагүй бол та нар аль эрт ухарч няцах байсан. Хүмүүсийн хэрэглэдэг заль мэхийг Би мэдэхгүй гэж үү? Ихэнх хүн одоо өчүүхэн найдлага өвөрлөдөг ч энэхүү найдлага нь урам хугаралт болж хувирахад тэд цааш явах хүсэлгүй болж, буцаад явъя гэж гуйдаг. Би хэнийг ч хүчээр үлдээхгүй гэдгээ өмнө нь хэлсэн, гэхдээ чиний хувьд ямар үр дагавар гарахыг сайн бодоорой. Энэ бол Би чамайг сүрдүүлж байгаа хэрэг биш, энэ бол бодит баримт юм. Хүний уг чанарыг Надаас өөр хэн ч ухан ойлгож чадахгүй; хүмүүс бүгд үнэнч байдал нь хир буртагтай гэдгийг мэдэхгүй, өөрсдийгөө Надад үнэнч гэж боддог. Энэхүү хир буртаг нь хүмүүсийг сүйрүүлнэ, учир нь тэдгээр нь агуу улаан лууны явуулга билээ. Би үүнийг аль эрт ил болгосон; Би бол төгс хүчит Бурхан, тиймээс ийм энгийн зүйлийг Би ойлгохгүй байж яаж болох билээ? Чиний санаа зорилгыг харахаар Би мах цусыг чинь нэвтлэх чадвартай. Хүний уг чанарыг ойлгох нь Миний хувьд хэцүү биш, харин хүмүүс өөрсдийгөө ухаантай гэж бодож, өөрсдөөс нь өөр хэн ч санаа зорилгыг нь мэдэхгүй гэж итгэдэг. Төгс хүчит Бурхан тэнгэр, газар, бүх зүйлийн дотор оршдог гэдгийг тэд мэддэггүй гэж үү?

Өөрийн Хүүг Би эцсээ хүртэл хайрлаж, агуу улаан луу болон Сатаныг үүрдийн үүрд үзэн ядах болно. Намайг эсэргүүцдэг бүх хүнд Миний гэсгээлт тусна, нэг ч дайсныг хэлтрүүлэхгүй. “Би Сионд том чулуу тавьдаг. Итгэгчдийн хувьд энэ чулуу нь тэдний барилгын суурь юм. Итгэдэггүй хүмүүсийн хувьд энэ нь тэдний бүдрэх чулуу билээ. Диаволын хөвгүүдийн хувьд энэ нь тэднийг бяц дарж алах чулуу юм” гэдгийг Би өмнө нь хэлсэн. Эдгээр үгийг Би урьд нь хэлсэн төдийгүй, олон хүн үүнийг зөгнөж, энэ эрин үед олон хүн энэ хэсэг үгийг уншсан. Мөн түүнчлэн, зарим хүн эдгээр үгийг тайлбарлах гэж оролдсон ч, хэн ч өмнө нь эдгээр нууцыг тайлсан удаа байхгүй, учир нь энэ ажил эцсийн өдрүүдийн энэ цаг үед л хийгддэг билээ. Иймд, хэдийгээр зарим хүн эдгээр үгийг тайлбарлах гэж оролдсон ч тэдний тайлбар нь бүгд төөрөгдөл юм. Өнөөдөр, Би та нарт бүхий л утгыг нь илчилсэн тул та нар, Өөрийн ууган хөвгүүдэд гэрчлэл хийж байгаагийн минь ноцтой байдал болон үүнийг хийж байгаа зорилгыг минь мэдэж магадгүй юм. Би Сионд том чулуу тавьдаг, энэ чулуу нь Миний ууган хөвгүүдэд гэрчлэл хийж байгааг хэлдэг. “Том” гэдэг үг нь гэрчлэлийг асар их далайцтайгаар хийсэн гэсэн үг биш, харин Миний ууган хөвгүүдэд гэрчлэл хийхдээ, үй олон үйлчлэл үзүүлэгч ухарч няцах болно

гэдгийг хэлж байгаа юм. Энд, “итгэдэггүй хүмүүс” гэдэг нь Миний Хүүд гэрчлэл хийснээс болж ухарч няцдаг хүмүүсийг хэлдэг. Тиймээс тэрхүү чулуу нь иймэрхүү хүмүүсийн хувьд бүдрэх хад юм. Би үүнийг хад гэж хэлж байгаа шалтгаан иймэрхүү хүн Миний гарт цохиулна, тиймээс хүмүүсийг бүдрэхэд хүргэдэг хад гэдгийг унах юм уу сул дорой болохтой холбоотойгоор хэлээгүй, харин Миний гарт цохиулахтай холбоотойгоор хэлсэн билээ. “Итгэгчдийн хувьд, энэ чулуу бол тэдний барилгын суурь” гэдгийн “итгэгчид” гэдэг нь үнэнч үйлчлэл үзүүлэгчдийг хэлдэг, харин “тэдний барилгын суурь” гэдэг нь Надад үнэнч үйлчлэл үзүүлснийхээ дараа тэдний хүлээн авах нигүүлсэл болон ерөөлийг хэлдэг. Ууган хөвгүүдэд гэрчлэл хийсэн гэдэг нь энэхүү хуучин эрин үе удахгүй бүхэлдээ өнгөрөн одно гэдгийг илтгэдэг; өөрөөр хэлбэл энэ нь Сатаны хаанчлалын сүйрлийг бэлгэддэг; тиймээс Харь үндэстнүүдийн хувьд, энэ нь тэднийг няц дарж алдаг хад юм. Иймд, бүх улс үндэстнийг хэдэн хэсэг болгон хагалан бутаргана гэдэг нь дэлхийг бүхэлд нь шинэчлэхийг хэлдэг; хуучин нь өнгөрөн одож, шинэ нь бүтээн байгуулагдана—энэ бол “хагалан бутаргах” гэдгийн жинхэнэ утга юм. Та нар ойлгож байна уу? Энэхүү эцсийн үе шатанд Миний хийдэг ажлыг энэ хэдхэн үгээр нэгтгэн дүгнэж болно. Энэ бол Миний гайхалтай үйл хэрэг, та нар Миний хүслийг Миний үгээс ухаарах ёстой.

119-Р БҮЛЭГ

Миний санаа зорилгыг та нар бүгд ухамсарлах ёстой, Миний сэтгэл санааны байдлыг та нар бүгд ойлгох учиртай. Одоо үе бол Сион руу буцахдаа бэлдэх цаг юм. Үүнээс өөр юу ч хийх бодол Надад алга. Би та нартай ойрын нэг өдөр уулзаж, минут, секунд бүрийг та нартай хамт Сионд өнгөрөөж чадна гэж л найдаж байна. Би дэлхий ертөнцийг үзэн яддаг, махан биеийг үзэн яддаг, газар дээрх хүн бүрийг бүр ч их үзэн яддаг. Би тэднийг харахыг хүсэхгүй байна, учир нь тэд бүгд өчүүхэн төдий ч хүний шинжгүй чөтгөрүүд билээ. Би газар дээр амьдрахыг хүсдэггүй; Би бүх бүтээлийг үзэн яддаг, мах, цустай бүхнийг үзэн яддаг. Бүх газар дэлхий цогцос ханхлуулдаг; Би цогцосны бүхий л өмхий үнэрийг газар дэлхийгээс арилгаж, Намайг магтах магтаалаар газар дэлхийг дүүргэхийн тулд Сионд даруй эргэн очихыг хүсэж байна. Би Сионд эргэн очиж, махан биеэс болон дэлхийгээс салах болно, хэн ч Миний замд саад болох ёсгүй. Хүнийг хөнөөдөг Миний гарт сэтгэл хөдлөл гэж үгүй! Одоогоос эхлээд хэн ч чуулганы бүтээн байгуулалтыг ярих ёсгүй. Тэгсэн хүнийг Би өршөөхгүй. (Учир нь одоо үе бол Миний ууган хөвгүүдийг гэрчилж, хаанчлалыг байгуулах цаг юм; чуулганы бүтээн байгуулалтын талаар ярьж буй хэн ч байсан хаанчлалын байгуулалтыг нурааж, Миний удирдлагад саад болж байна.) Бүгд бэлэн болж, бүгд бэлтгэгдсэн; ууган хөвгүүд өргөмжлөгдөж, гэрчлэгдэх л үлдсэн. Тийм зүйл тохиолдох үед Би хором ч сааталгүй, хэлбэрийг анхаарч үзэлгүйгээр та нарын өдөр, шөнөгүй оюун санаандаа тээдэг Сион руу тэр даруй

буцах болно. Одоогийн дэлхий ертөнц хэчнээн тайван, тогтвортой байгааг бүү хар. Энэ бүх ажил бол Сионд эргэн очих ажил тул эдгээр зүйлд одоо бүү анхаарал хандуул; Сион руу буцах өдөр ирэхэд бүгд бүрэн төгс болно. Сион руу түргэн буцахыг хүсдэггүй хэн байна вэ? Эцэг, хөвгүүд удахгүй нэгдэхийг хүсдэггүй хэн байна вэ? Газар дэлхийн таашаал хэчнээн таатай байлаа ч бидний махан биеэс зуурсаар байж чадахгүй; бид махан биеэ даван гарч, хамтдаа Сион руу буцна. Хэн үүнийг саатуулж зүрхлэх вэ? Хэн саад тотгор бий болгож зүрхлэх вэ? Би тэднийг мэдээж өршөөхгүй! Би бүх саад тотгорыг шүүрдэн хаяна. (Би Сион руу шууд буцаж чадахгүй гэж хэлдгийн минь шалтгаан нь энэ. Би энэ цэвэрлэгээний ажлыг хийхийн зэрэгцээ ууган хөвгүүддээ гэрчлэл хийж байна; энэ хоёр ажил нэгэн зэрэг урагшилж байгаа. Цэвэрлэгээний ажил дуусахад Миний хувьд ууган хөвгүүдээ илчлэх цаг ирнэ. “Саад тотгор” гэдэг нь олон тооны үйлчлэл үзүүлэгч бөгөөд ийм учраас Би энэ хоёр ажил нэгэн зэрэг явагдаж байна гэж хэлдэг.) Би орчлон ертөнц, газар дэлхийн зах хязгаар, уул толгод, гол горхи болон бүх зүйл даяар ууган хөвгүүдээ Өөртэйгөө цуг алхуулна; хэн үймүүлж зүрхлэх билээ? Хэн саатуулж зүрхлэх билээ? Миний гар ямар ч хүнийг амархан тавьж явуулахгүй; Би ууган хөвгүүдээсээ бусад хүмүүсийн эсрэг хилэгнэж, хараадаг. Бүх газар нутаг даяар Миний ерөөлийг хүлээж авдаг ганц ч эгэл хүн үгүй; бүгд Миний хараалтай тулгардаг. Дэлхийг бүтээснээс хойш Би хэнийг ч ерөөгөөгүй; Би ерөөл өгсөн ч гэсэн, энэ нь ердөө үг байсан ба хэзээ ч бодит байдал байгаагүй, учир нь Би Сатаныг дээд зэргээр үзэн яддаг; Би түүнийг хэзээ ч ерөөхгүй, зөвхөн шийтгэнэ. Эцэст нь Сатаныг бүрэн байлдан дагуулж, бүрэн ялсныхаа дараа л Би материаллаг ерөөлийг бүх үнэнч үйлчлэл үзүүлэгчид өгч, Намайг магтахдаа баярлан хөөрдөг болгоно, учир нь Миний бүх ажил гүйцэлдсэн байх болно.

Үнэн хэрэгтээ Миний цаг тийм ч холгүй байна. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нүдний чинь өмнө төгсгөлдөө ойртож байна. (Энэ нь үнэхээр нүдний чинь өмнө байгаа. Энэ нь урьдчилсан дүрслэл биш; үүнийг та нар Миний сэтгэл санааны байдлаас харж болно.) Өөрийн ууган хөвгүүдийг Би Сион руу даруй аваачна. Зарим хүн: “Ууган хөвгүүдийн л төлөө байж яагаад энэ нь зургаан мянган жилийн хугацааг зарцуулдаг юм бэ? Яагаад маш олон хүнийг бүтээсэн юм бэ?” хэмээн хэлдэг. Миний бүх зүйл үнэ цэнтэй гэж Би өмнө нь хэлсэн. Миний ууган хөвгүүд яахаараа бүр ч илүү үнэ цэнтэй биш байх юм бэ? Би бүхнийг дайчлан Өөртөө үйлчлүүлнэ, мөн түүнчлэн Өөрийн хүч чадлыг илчилнэ, ингэснээр л бүх орчлон ертөнц дээр бидний гарт байдаггүй нэг ч юм байхгүй, бидэнд үйлчилдэггүй нэг хүн ч байхгүй, бидний төлөө гүйцэлдээгүй нэг ч зүйл үгүй гэдгийг хүн бүр харж чадна. Би бүхнийг биелүүлнэ. Надад цаг хугацааны ухагдахуун гэж байхгүй; хэдийгээр Би төлөвлөгөө болон Өөрийн ажлыг зургаан мянган жилд гүйцэлдүүлэх гэж байгаа ч Надад бүх зүйл чөлөөлөгдсөн, эрх чөлөөтэй байдаг. Зургаан мянган жилээс бага байлаа ч гэсэн, Миний үзэл бодлоор цаг нь болсон л бол хэн болоогүй гэж хэлж зүрхлэх билээ? Хэн босож, хүссэнээрээ шүүж зүрхлэх

билээ? Өөрийн ажлыг Би Өөрөө хийдэг; Өөрийн цаг хугацааг Би Өөрөө зохицуулдаг. Ямар ч хүн, ямар ч юм, ямар ч зүйл дураараа авирлаж зүрхлэхгүй; Би бүхнээр Өөрийгөө дагуулах болно. Надад зөв юм уу буруу гэж байхгүй; хэрвээ Би үүнийг зөв гэж хэлбэл энэ нь мэдээжийн хэрэг зөв; хэрвээ Би ямар нэг зүйлийг буруу гэж хэлбэл энэ бас л тийм байна. Та нар Намайг үргэлж хүний үзлээр хэмжих ёсгүй! Ууган хөвгүүд Надтай хамт ерөөгдсөн гэж Би хэлдэг—хэн захирагдахаас татгалзаж зүрхлэх билээ? Би чамайг байгаа газар чинь устгах болно! Чи захирагдахаас татгалздаг! Чи бол тэрслүү! Надад хүн төрөлхтнийг гэх өршөөл огтоос байхгүй, Миний үзэн ядалт аль хэдийн хязгаартаа тулсан; Би цаашид хүлээцтэй байж ер чадахгүй. Миний тухайд гэвэл, бүхий л орчлон ертөнцийг тэр даруй үгүй хийх ёстой—тэр үед л Миний агуу ажил биелнэ; тэр үед л Миний удирдлагын төлөвлөгөө гүйцэлдэнэ; тэр үед л Миний зүрх сэтгэл дэх үзэн ядалт сарних болно. Одоо Би Өөрийн ууган хөвгүүдийг гэрчлэхэд л анхаардаг. Би бусад бүх хэргийг хойш тавина; Би чухал зүйлсийг эхлээд хийнэ, дараа нь хоёрдогч зүйлсийг хийнэ. Эдгээр нь Миний ажлын алхам, хэн ч үүнийг зөрчих ёсгүй; Миний хараалын бай болохгүйн тулд бүгдээрээ Миний хэлснээр хийх ёстой.

Одоо Миний ажил гүйцэлдсэн болохоор Би амарч болно. Одоогоос эхлээд Би дахиж ажиллахгүй, харин хийхийг хүссэн бүхнээ ууган хөвгүүдээрээ хийлгэхээр даатгах болно, учир нь Миний ууган хөвгүүд бол Би; Миний ууган хөвгүүд бол Миний үнэн бие юм. Энэ нь өчүүхэн төдий ч буруу биш; өөрсдийнхөө үзлийг ашиглан бүү шүү. Ууган хөвгүүдийг харах нь Намайг харахтай адил, учир нь бид угаасаа нэг билээ. Биднийг салгадаг хэн ч Намайг эсэргүүцэж байгаа ба Би түүнийг өршөөхгүй. Миний үгэнд хүн ойлгохын аргагүй нууцууд бий. Миний хайрладаг хүмүүс л Намайг илэрхийлж чадна, бусад нь чадахгүй; үүнийг Би тодорхойлсон ба хэн ч өөрчилж чадахгүй. Миний үг арвин баялаг, иж бүрэн бөгөөд ойлгошгүй. Хүн бүхэн Миний үгэнд асар их хүчин чармайлт гаргаж, тэдгээрийг үргэлж тунгаан бодохоор хичээ, ганц ч үг, өгүүлбэр бүү орхигдуул—эс тэгвээс хүмүүс эндүү ташаа бодож, Миний үгийг буруугаар ойлгоно. Миний зан чанар халдахыг тэвчдэггүй гэж хэлсэн минь Миний гэрчилсэн ууган хөвгүүдийг хэн ч эсэргүүцэж болохгүй гэсэн утгатай. Миний зан чанарын тал бүрийг Миний ууган хөвгүүд төлөөлдөг тул ариун бүрээ дуугарах үед Би ууган хөвгүүдээ гэрчилж эхэлдэг, иймд үүнээс хойш, ариун бүрээ Миний зан чанарыг аажмаар олон нийтэд зарлан мэдэгдэнэ. Өөрөөр хэлбэл, ууган хөвгүүд илчлэгдэх цаг бол Миний зан чанар илчлэгдэх цаг юм. Хэн үүнийг ухан ойлгож чадах билээ? Миний илчилсэн нууцууд дунд ч хүмүүсийн тайлж чаддаггүй нууц байсаар байдаг гэж Би хэлдэг. Та нарын дундаас хэн чинь эдгээр үгийн жинхэнэ утгыг олж мэдэхээр үнэхээр оролдсон бэ? Миний зан чанар та нарын төсөөлсөн шиг хүний зан ааш мөн үү? Тэгж бодох нь ноцтой алдаа юм! Өнөөдөр Миний ууган хөвгүүдийг харсан хэн боловч Миний ерөөлийн бай болж, Миний зан чанарыг хардаг—энэ бол туйлын үнэн. Миний ууган хөвгүүд Намайг бүхэлд нь төлөөлдөг; тэд бол ямар ч эргэлзээгүй Миний үнэн бие юм. Энэ талаар хэн ч

эргэлзэж болохгүй! Дуулгавартай хүмүүс нигүүлслээр ерөөгдөж, тэрслүү нь хараагддаг. Энэ бол Миний тушаал, хэн ч үүнийг өөрчилж чадахгүй!

120-Р БҮЛЭГ

Сион! Уухайл! Сион! Дуул! Би ялалтаар ирлээ, Би ялгууснаар ирлээ! Бүх хүмүүс ээ! Дараалалдаа хурдан жагс! Бүтээлийн бүх зүйл ээ! Одоо зогсоцгоо, учир нь Миний үнэн бие бүхий л орчлон ертөнцтэй нүүр тулж, дэлхийн Зүүн зүгт гарч ирлээ! Хэн өвдөг сөгдөн шүтэн мөргөхгүй байж зүрхлэх билээ? Хэн Намайг жинхэнэ Бурхан гэж дуудахгүй байж зүрхлэх билээ? Хэн хүндэтгэлтэйгээр харахгүй байж зүрхлэх билээ? Хэн магтаал өргөхгүй байж зүрхлэх билээ? Хэн баярлан хөөрөхгүй байж зүрхлэх билээ? Миний ардууд Миний дуу хоолойг сонсож, Миний хаанчлал дотор хөвгүүд минь амьд үлдэнэ! Уулс, гол мөрөн болон бүх зүйл эцэс төгсгөлгүй уухайлж, зогсолтгүй үсэрч харайна. Энэ үед хэн ч ухарч няцаж зүрхлэхгүй, хэн ч өндийн босож эсэргүүцэж зүрхлэхгүй. Энэ бол Миний гайхалтай үйл хэрэг, үүнээс ч илүүтэйгээр Миний агуу хүч чадал! Би бүх зүйлийн зүрх сэтгэлд Өөрийгөө хүндлүүлж, бүх зүйлээр Өөрийгөө магтуулна! Энэ бол Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний эцсийн зорилго бөгөөд Миний урьдчилан тодорхойлсон зүйл билээ. Нэг ч хүн, ганц ч эд зүйл, нэг ч үйл явдал Намайг эсэргүүцэж, эсвэл Намайг сөрж зүрхэлдэггүй. Миний ардууд бүгд Миний уул руу (өөрөөр хэлбэл, хожим нь Миний бүтээх дэлхий рүү) цувж, Миний өмнө захирагдана, учир нь Надад сүр жавхлан, шүүлт байдаг ба Би эрх мэдэл агуулдаг билээ. (Энэ нь, Намайг биед байх үеийг хэлдэг. Махбодод Надад бас эрх мэдэл байдаг боловч цаг хугацаа болон орон зайн хязгаарыг махбодоор давж чадахгүй тул Намайг бүрэн алдрыг олж авсан гэж хэлж болохгүй. Хэдийгээр Би ууган хөвгүүдийг махбодоор олж авдаг ч алдрыг олж авсан гэж хэлж бас л болохгүй. Зөвхөн Сион руу буцаж, Өөрийн дүрийг өөрчлөх үед л Намайг эрх мэдэлтэй буюу алдрыг олж авсан гэж хэлж болох юм.) Надад юу ч хэцүү байхгүй. Бүгд Миний амнаас гардаг үгээр устгагдана, мөн Миний амнаас гардаг үгээр бүгд бий болж, гүйцэлдэнэ. Энэ бол Миний агуу хүч чадал, Миний эрх мэдэл билээ. Би хүч чадлаар дүүрэн агаад эрх мэдлээр бялхаж байдаг учир хэн ч Надад саад хийж зүрхлэхгүй. Би хэдийнээ бүх зүйлийг дийлж, бүх тэрслүү хөвгүүдийг аль хэдийн ялсан. Би Сион руу буцахдаа ууган хөвгүүдээ аваад явж байгаа. Би ганцаараа Сион руу буцаагүй. Тиймээс бүгд Миний ууган хөвгүүдийг харж, улмаар Намайг хүндэтгэх зүрх сэтгэлтэй болно. Энэ бол ууган хөвгүүдийг олж авах Миний зорилго бөгөөд энэ нь дэлхийг бүтээсэн цагаас хойш Миний төлөвлөгөө байсаар ирсэн билээ.

Бүх зүйл бэлэн байх үе бол Миний Сион руу буцах өдөр бөгөөд энэ өдрийг бүх хүн тэмдэглэнэ. Намайг Сион руу буцахад газар дээрх бүх зүйл нам гүм байна, газар дээрх бүх зүйл амар тайван байна. Намайг Сион руу буцахад бүгд анхдагч

байдалдаа орно. Тэгээд Би Сион дахь ажлаа эхлүүлнэ. Би мууг шийтгэж, сайныг шагнаж, зөвт байдлаа хэрэгжүүлж, шүүлтээ гүйцэтгэнэ. Би үгээ ашиглан бүх зүйлийг гүйцэлдүүлж, бүх хүн, бүх зүйлд Өөрийн гэсгээгч гарыг мэдрүүлж, бүх хүнд Өөрийн бүрэн алдар, Өөрийн бүх мэргэн ухаан, Өөрийн бүрэн элбэг байдлыг харуулна. Миний дотор бүх зүйл гүйцэлдсэн учир хэн ч өндийн босож шүүмжилж зүрхлэхгүй; Миний дотор бүх зүйл харагддаг учир үүнээс хүн бүр Миний бүхий л эрхэм чанарыг харж, Миний бүрэн ялалтыг амтална. Үүнээс Миний агуу хүч чадал болон эрх мэдлийг харах боломжтой. Хэн ч Надад халдаж, Надад саад болж зүрхлэхгүй. Миний хувьд бүх зүйл ил тод байдаг. Хэн юм нууж зүрхлэх билээ? Би тэр хүнд өршөөл үзүүлэхгүй нь гарцаагүй! Тийм өөдгүй хүмүүс Миний хатуу шийтгэлийг хүртэх ёстой ба тийм өөдгүй амьтдыг Миний нүднээс далд оруулах ёстой. Би өчүүхэн ч өршөөлгүйгээр, сэтгэлийг нь шархлуулахаас зайлсхийлгүйгээр төмөр саваагаар тэднийг захирч, эрх мэдлээ ашиглан тэднийг шүүнэ, учир нь Би бол сэтгэл хөдлөлгүй, сүр жавхлант, халдашгүй Бурхан Өөрөө билээ. Надад халддаг бүх хүнийг Миний төмөр саваа цохих учраас Надад “учир, шалтгаангүйгээр” цохиулж, сүйрэхгүйн тулд бүгд үүнийг ойлгож, харах ёстой. Тэд Миний захиргааны зарлигийг мэддэг эсэхийг Би тоодоггүй; тэр нь Надад хамаагүй, учир нь Миний үнэн бие хэний ч халдахыг тэвчиж чадахгүй. Намайг арслан гэж хэлсний шалтгаан нь энэ; Би хүрсэн хүн болгоноо цохино. Тийм учраас одоо Намайг өршөөнгүй агаад элэгсэг Бурхан гэж дуудах нь Намайг доромжилж байгаа хэрэг гэж хэлдэг. Мөн чанартаа Би хурга биш, харин арслан. Хэн ч Надад халдаж зүрхэлдэггүй; Надад халддаг хэнийг ч Би нэн даруй, өршөөлгүйгээр, үхлээр шийтгэнэ! Энэ нь Миний зан чанарыг харуулахад хангалттай. Тиймээс, эцсийн эрин үед томоохон бүлэг хүмүүс ухарч буцна, энэ нь хүмүүсийн хувьд тэвчихийн аргагүй байх боловч Миний хувьд бол Би хөнгөн хялбар агаад баяр хөөртэй байж, үүнийг огтхон ч хэцүү зүйл гэж хардаггүй. Энэ нь Миний зан чанар юм.

Бүх хүн Надаас ирдэг бүхнийг дуулгавартай дагах зүрх сэтгэлтэй байгаасай гэж Би найддаг; тэгвэл Би хүн төрөлхтнийг ихэд ерөөх нь гарцаагүй, учир нь Надтай нийцдэг хүмүүс үлдэж, Надтай дайсагнадаг хүмүүс хараагдана гэж Би хэлсэн билээ. Би үүнийг урьдчилан тогтоосон, хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Миний тогтоосон зүйл бол Миний гүйцэлдүүлсэн зүйл бөгөөд тэдгээрийг зөрчдөг хэн ч бай, даруй гэсгээгдэнэ. Надад хэрэгтэй, Миний хүсдэг бүх зүйл Сионд бий. Сионд дэлхий ертөнцийн ямар ч өнгө аяс байхгүй, дэлхийтэй харьцуулахад энэ нь тансаг, сүрлэг ордон юм; гэхдээ хэн ч үүнд орж байгаагүй, тиймээс энэ нь хүний төсөөлөлд огтхон ч оршдоггүй. Сион дахь амьдрал газар дээрх амьдралтай адилгүй; газар дээрх амьдрал нь идэж, хувцаслаж, тоглож наадаж, зугаа цэнгэл хөөцөлдөх явдал байхад Сионд энэ нь асар өөр. Энэ бол Эцэг, хөвгүүд баяр хөөрт умбан, орчлон ертөнцийн бүхий л орон зайг үргэлж дүүргэдэг мөртөө бас үргэлж нэгэн дуугаар цугладаг амьдрал билээ. Өнөөдөр нэгэнт энэ үе шатанд хүрсэн учир Би та нарт Сион хаана байрладгийг хэлье. Сион бол Миний оршин суудаг газар, Миний үнэн

биеийн байршил юм. Тиймээс, Сион нь ариун газар байх ёстой бөгөөд дэлхийгээс хол байх ёстой. Тийм учраас Би газрын хүмүүс, зүйлс, хэрэг явдлуудыг үзэн ядаж, бие махбодын идэж, ууж, тоглож, зугаацаж цэнгэхийг жигшдэг гэж хэлдэг, учир нь газар дэлхийн зугаа цэнгэл хэчнээн таатай байлаа ч, тэдгээрийг Сионы амьдралтай харьцуулж болохгүй; энэ нь тэнгэр, газар шиг ялгаатай бөгөөд энэ хоёрыг харьцуулах ямар ч аргагүй. Дэлхий дээр хүний тайлж чадахгүй олон оньсого байдгийн шалтгаан нь хүн Сионы талаар юу ч сонсоогүйгээс болдог. Тэгвэл, Сион яг хаана байдаг юм бэ? Энэ нь хүмүүсийн төсөөлдөг шиг харь гарагт байдаг уу? Үгүй! Тэр бол ердөө хүмүүсийн оюун санаан дахь төсөөлөл. Миний дурдсан гуравдагч тэнгэрийг хүмүүс бэлгэдлийн утгатай хэмээн үздэг ч хүмүүсийн үзэл дэх ойлголт Миний хэлэх гэснээс яг эсрэг байдаг. Энд дурдсан гуравдагч тэнгэр нь өчүүхэн ч худлаа биш. Тийм учраас Би, нар, сар, одод, эрхсийг устгахгүй, бас тэнгэр, газрыг үгүй хийхгүй гэж хэлдэг. Би Өөрийн оршин суудаг газрыг устгаж болно гэж үү? Сион уулыг үгүй хийж болно гэж үү? Энэ нь инээдтэй хэрэг биш үү? Гуравдагч тэнгэр бол Миний оршин суудаг газар; энэ бол Сион уул бөгөөд энэ нь туйлын юм. (Би яагаад энэ бол туйлын гэж хэлдэг вэ? Учир нь Миний одоо хэлдэг зүйлийг хүн огт ойлгож чадахгүй, сонсож л чадна. Хүний бодлын цар хүрээ үүнийг огтхон ч ухамсарлаж чадахгүй, тиймээс хүмүүс үүнийг үлгэр гэж бодох вий гэсэндээ Би Сионы талаар одоо дахиад ярихгүй.)

Намайг Сион руу буцсаны дараа газар дээрх хүмүүс урьдын адилаар Намайг үргэлжлүүлэн магтана. Тэдгээр үнэнч үйлчлэл үзүүлэгч Надад үйлчлэхээр хүлээсээр байх боловч тэдний чиг үүрэг эцэс болчихсон байх болно. Тэдний хамгийн сайн хийж чадах зүйл гэвэл газар дээр байх үеийн минь орчин нөхцөлийг дурсан санагалзах явдал юм. Тэр үед Би гай гамшиг амсах хүмүүс дээр гамшиг буулгаж эхэлнэ; гэсэн ч Намайг зөвт Бурхан гэдэгт хүн бүр итгэдэг. Би тэдгээр үнэнч үйлчлэл үзүүлэгчийг гарцаагүй шийтгэхгүй, харин тэдэнд Өөрийн нигүүлслийг л хүртээнэ. Би бүх мууг үйлдэгчийг шийтгэнэ, сайн үйл хийгсэд Миний хайрладаг материаллаг зүйлсийг эдэлнэ гэж хэлсэн нь Би бол зөвт бөгөөд итгэмжит Бурхан Өөрөө гэдгийг харуулдаг. Сион руу буцахдаа Би дэлхийн улс үндэстэн болгонд хандаж эхэлнэ; Би израильчуудад аврал авчирч, египетчүүдийг гэсгээнэ. Энэ бол Миний ажлын дараагийн алхам юм. Тухайн үеийн Миний ажил өнөөгийнхтэй адилгүй байх болно: Энэ нь махбод дахь ажил биш, харин махбодыг бүрэн давж гарна—Миний хэлснээр хийгдэж, Миний тушааснаар бат зогсоно. Юу ч хэлсэн бай, Миний амаар хэлэгдсэн цагт, энэ нь бодит байдал дээр даруй биелнэ; энэ бол Миний үг болон үйлдэл зэрэгцэн явагдаж байгаагийн жинхэнэ утга юм, учир нь Миний үг өөрөө эрх мэдэл билээ. Газар дээрх хүмүүст буруу зөрүү ухааруулалгүй, цөөн хэдэн сэжүүр өгөх үүднээс Би зарим ерөнхий зүйлийн талаар одоо ярьж байна. Цаг нь ирэхэд Би бүх зүйлийг зохицуулах бөгөөд Миний гарт цохиулахгүйн тулд хэн ч дур зоргоороо аашлах ёсгүй. Хүмүүсийн төсөөлөлд, Миний хэлдэг бүхэн тодорхойгүй хийсвэр байдаг, учир нь эцсийн эцэст хүний

сэтгэлгээ хязгаарлагдмал бөгөөд хүний бодол, Миний ярьсан зүйл хоёр тэнгэр газар шиг зөрүүтэй. Тиймээс, хэн ч үүнийг ухамсарлаж чадахгүй. Миний хэлсний дагуу үйлдэхээс өөр сонголтгүй, энэ бол зайлшгүй чиг хандлага юм. “Эцсийн өдрүүдэд, Миний ардуудыг хяхан хавчих араатан гарч ирнэ, үхлээс айдаг хүмүүсийг араатанд өгч явуулахын тулд тамгаар тамгална. Намайг харсан хүмүүсийг араатан хөнөөнө” гэж Би хэлсэн. Энэ үгэн дэх “араатан” гэдэг нь хүн төрөлхтнийг мэхэлдэг Сатаныг хэлдэг нь эргэлзээгүй. Өөрөөр хэлбэл, Намайг Сион руу буцахад үйлчлэл үзүүлэгчдийн томоохон бүлэг ухарч няцна; өөрөөр хэлбэл, тэд араатанд олзлогдоно. Эдгээр бүтээл бүгд Миний мөнхийн гэсгээлтийг хүртэхээр ёроолгүй нүхэнд орно. “Намайг харсан хүмүүс” гэдэг нь Миний байлдан дагуулсан үнэнч үйлчлэл үзүүлэгчдийг хэлж байгаа юм. “Намайг харсан” гэдэг нь Надаар байлдан дагуулагдсан гэдгийг хэлдэг. “Араатан хөнөөнө” гэдэг нь Надаар байлдан дагуулагдсан Сатан Намайг эсэргүүцэхээр босож зүрхлэхгүй байхыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, Сатан эдгээр үйлчлэл үзүүлэгч дээр ямар ч ажил хийж зүрхлэхгүй бөгөөд тиймээс энэ хүмүүсийн сүнс аврагдсан байх болно; тэд Надад үнэнч байх чадвартай учраас ингэж хэлдэг бөгөөд тэрхүү үнэнч үйлчлэл үзүүлэгчид Миний нигүүлсэл, ерөөлийг хүртэж чадна гэсэн үг юм. Тиймээс, тэдний сүнс аврагдсан байх болно гэж Би хэлдэг. (Энэ нь гуравдагч тэнгэр өөд өргөгдөхийг хэлдэггүй, энэ нь зүгээр л хүний үзэл юм.) Гэхдээ тэрхүү муу зарц нар Сатанд дахин хүлэгдээд, дараа нь ёроолгүй нүхэнд хаягдана. Энэ бол тэдэнд өгөх Миний шийтгэл, тэдний залхаан цээрлүүлэлт бөгөөд нүглийнх нь төлөөс юм.

Миний ажлын алхаа хурдсахын хэрээр газар дээрх Миний цаг хугацаа аажмаар багасдаг. Сион руу буцах өдөр минь ойртож байна. Газар дээрх Миний ажил дуусах үе Сион руу буцах цаг байх болно. Би газар дээр амьдрахыг огт хүсдэггүй боловч Өөрийн удирдлага, Өөрийн төлөвлөгөөний төлөө бүх зовлонг тэвчсэн. Өнөөдөр, цаг нь хэдийнээ ирсэн. Би алхаагаа түргэсгэх бөгөөд хэн ч Надтай хөл нийлүүлэн алхаж чадахгүй. Хүмүүс ойлгож чадах ч бай, үгүй ч бай, хүн ухамсарлаж чаддаггүй боловч газар дээр мэдэх ёстой бүхнийг чинь Би та нарт нарийвчлан хэлж өгнө. Тиймээс, Би бол цаг хугацаа, орон зайг даван гардаг Бурхан Өөрөө мөн гэж Би хэлдэг. Ууган хөвгүүдийг олж авч, улмаар Сатаныг ялах зорилготой байгаагүй сэн бол Би Сион руу хэдийн буцчих байсан; эсвэл Би хүн төрөлхтнийг зүгээр л огт бүтээхгүй байх байсан юм. Би хүний ертөнцийг үзэн яддаг, мөн ганцхан цохилтоор бүх хүн төрөлхтнийг сөнөөхийг бодож үзэх хэмжээнд хүртлээ Өөрөөсөө бусад хүнийг жигшдэг. Хэдий тийм ч, Миний ажил дэс дараа болон бүтэцтэй, донжийг нь тааруулах чадвар болон хэмжээ хязгаартай байдаг ба үүнийг дурааараа хийдэггүй. Миний хийдэг бүхэн Сатаныг ялахын төлөө, үүнээс ч илүүтэйгээр ууган хөвгүүдтэйгээ аль болох хурдан хамт байхын төлөө байдаг. Энэ бол Миний зорилго юм.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД

(1992 ОНЫ 2-Р САРЫН 20—1992 ОНЫ 6-Р САРЫН 1)

ОРШИЛ

“Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд” бол Христ, Бурханы Өөрийн ялгамж чанарыг ашиглан илэрхийлсэн айлдваруудын хоёр дахь хэсэг юм. Тэдгээр нь 1992 оны 2 дугаар сарын 20-ноос 1992 оны 6 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацааг хамардаг бөгөөд нийт дөчин долоон бүлгээс бүрддэг. Эдгээр айлдвар дахь Бурханы үгийн арга зам, агуулга, өнцөг нь “Христийн эхэн үеийн айлдварууд”-тай огт адилгүй. “Христийн эхэн үеийн айлдварууд” нь хүмүүсийн гаднах зан авир болон энгийн сүнслэг амьдралыг илчилж, залж чиглүүлдэг. Эцэстээ энэ нь “үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт”-аар өндөрлөдөг. Харин “Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд” нь хүмүүсийн үйлчлэл үзүүлэгч гэх ялгамж чанарын төгсгөл болон Бурханы ард гэх амьдралын гараагаар нь эхэлдэг. Энэ нь хүмүүсийг Бурханы ажлын хоёр дахь оргил үе рүү залж чиглүүлдэг бөгөөд энэ явцад тэд галт нуурын шалгалт, үхлийн шалгалт болон Бурханыг хайрлах цаг үеийг туулдаг. Энэ хэдэн алхам нь Бурханы өмнө хүний муу муухай байдлыг болон үнэн царайг бүрэн илчилдэг. Эцэст нь Бурхан, хүнээс салж явсан бүлгээр төгсгөл болгон, Бурхан энэ удаа бие махбодтой болоод эхний бүлэг хүмүүсийг байлдан дагуулах бүх алхмыг дуусгадаг.

“Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд” Бурхан Сүнсний өнцгөөс Өөрийн үгийг илэрхийлдэг. Түүний үгээ хэлэх арга барилд бүтээгдсэн хүн төрөлхтөн хүрэхийн аргагүй юм. Цаашлаад Түүний үгсийн үгийн сан, хэв маяг нь сайхан агаад сэтгэл хөдлөм, хүмүүний уран зохиолын ямар ч хэлбэр тэдгээрийг орлож чадахгүй. Хүнийг илчилдэг Түүний үг үнэн зөв, ямар ч гүн ухаанаар няцаагдашгүй бөгөөд тэдгээр нь бүх хүнийг дуулгавартай байдалд хүргэдэг. Хүнийг шүүдэг Түүний үг нь хурц сэлмийн адилаар хүмүүсийн сэтгэлийн гүн рүү шууд цавчиж, тэднийг бүр нуугдах ч газаргүй болгодог. Хүмүүсийг тайвшруулдаг Түүний үг өршөөл энэрэл, элэгсэг сэтгэлийг агуулдаг, тэдгээр нь энэрэлт ээжийн тэврэлт шиг халуун дулаан бөгөөд хүмүүсийг өмнө нь хэзээ ч байгаагүйгээр тайвшруулдаг. Эдгээр айлдварын ганц агуу шинж чанар нь, энэ үе шатанд Бурхан, Ехова эсвэл Есүс Христийн, мөн эцсийн өдрүүдийн Христийн ялгамж чанарыг ашиглан яриагүй юм. Үүний оронд Бүтээгч хэмээх Өөрийн төрөлхийн ялгамж чанарыг ашиглан Тэр, Түүнийг дагаж байгаа болон Түүнийг хараахан дагаагүй байгаа бүх хүнд ярьж, сургадаг. Дэлхий бүтээгдсэнээс хойш Бурхан анх удаа бүх хүн төрөлхтөнд хандан үгээ хэлж байгаа нь энэ юм гэдгийг хэлэх нь зүйтэй. Бурхан өмнө нь хэзээ ч бүтээгдсэн хүн төрөлхтөнтэй ийм дэлгэрэнгүй, маш дэс дараатайгаар ярьж байгаагүй билээ. Мэдээж энэ нь бас Тэр бүх хүн төрөлхтөнд маш ихийг, маш удаан хугацаанд ярьсан анхны тохиолдол юм. Энэ нь урьд өмнө огт үзэгдээгүй билээ. Үүнээс гадна, эдгээр айлдвар нь хүн төрөлхтний дунд Бурханы илэрхийлсэн анхны эх бичвэрүүд бөгөөд түүгээрээ Тэр хүмүүсийг ил болгож, удирдан чиглүүлж, шүүж, тэдэнтэй чин сэтгэлээсээ ярьсан тул тэдгээр нь бас Бурхан хүмүүст Өөрийн

мөрийг, Өөрийн оршдог газрыг, Бурханы зан чанарыг, Бурханд юу байгаа, Тэр юу болохыг, Бурханы бодол болон хүн төрөлхтнийг гэх Өөрийн халамжийг мэдэгдсэн анхны айлдварууд юм. Эдгээр нь бүтээлийн цаг үеэс хойш Бурхан хүн төрөлхтөнтэй гуравдагч тэнгэрээс ярьсан эхний айлдварууд бөгөөд Бурхан үгсийн дундаас хүн төрөлхтөнд үзэгдэж, зүрх сэтгэлийнхээ дуу хоолойг илэрхийлэхийн тулд төрөлхийн ялгамж чанараа ашигласан анхны удаа юм гэж хэлж болно.

Эдгээр айлдвар гүн гүнзгий агаад ойлгогдошгүй; тэдгээрийг ойлгоход амархан биш, мөн Бурханы үгийн гарал үүсэл болон зорилгыг ухаарах боломжгүй. Тиймээс айлдварын дийлэнх хэсгийг тодорхой болгохын тулд Христ, хүний хувьд ойлгоход амархан хэлийг ашиглан бүлэг болгоны дараа тайлбар нэмсэн юм. Энэ нь айлдваруудтай хамт нийлээд хүн бүрийн хувьд Бурханы үгийг ойлгож мэдэхэд илүү амархан болгосон. Бид эдгээр үгийг “Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд”-ын хавсралт болгосон. Тэдгээрт Христ, ойлгоход хамгийн амархан найруулгыг ашиглан тайлбар хийсэн билээ. Энэ хоёрын хослол нь бурханлаг чанар болон хүн чанар дахь Бурхан хоёрын төгс нийлэмж юм. Хэдийгээр Бурхан хавсралт дээр гуравдагч хүний өнцгөөс ярьсан боловч эдгээр үгийг Бурхан биечлэн айлдсан гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй, учир нь ямар ч хүн Бурханы үгийг тайлбарлаж чадахгүй; зөвхөн Бурхан Өөрөө л Өөрийн үгийн эх сурвалж болон зорилгыг тодруулан тайлбарлаж чадна. Тиймээс хэдийгээр Бурхан олон арга барил ашиглан ярьдаг боловч Түүний ажлын зорилтууд хэзээ ч өөрчлөгдөхгүй, мөн Түүний төлөвлөгөөний зорилго хэзээ ч хувирахгүй.

Хэдийгээр “Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд” нь Бурхан хүнээс салж одсон бүлгээр төгсдөг боловч үнэндээ энэ нь хүмүүсийн дундах Бурханы байлдан дагуулалт, авралын ажил болон хүмүүсийг төгс болгох Түүний ажил албан ёсоор эхэлсэн үе байсан юм. Тиймээс бидний хувьд “Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд”-ыг эцсийн өдрүүд дэх Бурханы ажлын тухай зөгнөлүүд хэмээн үзэх нь илүү зохистой. Учир нь зөвхөн энэ мөчөөс хойш бие махбодтой болсон хүний Хүү Христийн ялгамж чанарыг ашиглан албан ёсоор ярьж, ажиллаж эхэлсэн бөгөөд чуулгануудын хоорондявж, амиар хангаж, Өөрийн бүх хүнийг усалж, хариулсан ба энэ нь “Чуулгануудаар явахдаа Христийн хэлсэн үг” дэх олон айлдварыг бий болгосон билээ.

1-Р БҮЛЭГ

Миний үгийг харсан хүмүүс тэдгээрийг үнэхээр хүлээн авдаг уу? Та нар Намайг үнэхээр мэддэг үү? Та нар дуулгавартай байж үнэхээр сурсан уу? Миний төлөө та нар өөрсдийгөө чин сэтгэлээсээ зарлагаддаг уу? Та нар агуу улаан лууны эсрэг Надад хүчтэй, гуйвшгүй гэрчлэл үнэхээр хийсэн үү? Та нарын үнэнч зан агуу улаан лууг үнэхээр шившиглэдэг үү? Би чуулганыг ариусгах, мөн Намайг үнэхээр

хайрладаг хүмүүсийг сонгох зорилгоо Өөрийн үгийн шалгалтаар л дамжуулан биелүүлж чадна. Хэрвээ Би ийм маягаар ажиллаагүй бол хүн Намайг мэдэж чадна гэж үү? Миний үгээр дамжуулан Миний сүр жавхлан, уур хилэн, мэргэн ухааныг хэн мэдэж чадах юм бэ? Би ажлаа эхлүүлсэн, түүнийгээ заавал дуусгана, гэхдээ хүмүүсийн зүрх сэтгэлийг гүнд нь хүртэл хэмждэг нь мөн л Би билээ. Үнэндээ нэг ч хүн Намайг бүрэн мэддэггүй, иймээс Би бүх хүнийг үгээр залж, ийм маягаар шинэ эрин рүү хөтөлдөг. Эцэст нь Би үг ашиглан Өөрийн бүх ажлыг гүйцэлдүүлж, Намайг чин сэтгэлээсээ хайрладаг бүх хүнийг Миний хаанчлалд дуулгавартай буцаж ирээд Миний сэнтийн өмнө амьдардаг болгоно. Нөхцөл байдал урьдынх шигээ биш болж, Миний ажил шинэ эхлэлд орсон. Тийм болохоор шинэ арга барил байх болно: Миний үгийг уншиж, үүнийг өөрсдийн амь хэмээн хүлээн авдаг хүмүүс Миний хаанчлалд байдаг бөгөөд тэд Миний хаанчлалд байдаг болохоор Миний хаанчлалын ардууд билээ. Миний үгийг удирдамж болгодог учраас тэднийг Миний ардууд гэдэг хэдий ч энэ цол нь Миний “хөвгүүд” гэж дуудуулахаас огтхон ч дорд биш юм. Бурханы ард болчихсоныхоо дараа бүгд Миний хаанчлалд дээд зэргээр үнэнч зүтгэж, үүргээ биелүүлэх ёстой. Миний захиргааны зарлигийг зөрчсөн хэн ч атугай Миний шийтгэлийг хүртэх ёстой. Энэ бол бүгдэд өгөх Миний зөвлөгөө билээ.

Одоо шинэ арга барил ашиглаж байгаа болохоор өнгөрснийг дахин дурдах хэрэггүй. Гэсэн хэдий ч Би урьд эдгээр үгийг хэлсэн: Би хэлсэн үгэндээ эзэн болдог бөгөөд эзэн болсон үгээ үргэлж гүйцэлдүүлдэг ба үүнийг хэн ч өөрчилж чадахгүй—энэ бол хөдөлшгүй. Урьдын цагт хэлсэн үгээ ч, ирээдүйд хэлэх үгээ ч Би бүгдийг нэг нэгээр нь биелүүлэх бөгөөд бүх хүн төрөлхтөнд үүний биелэхийг харуулна. Энэ бол Миний үг болон ажлын цаад зарчим билээ. Чуулганы бүтээн байгуулалт аль хэдийн бүтсэн учраас одоо чуулганыг байгуулах эрин үе байхаа больсон, харин ч энэ нь хаанчлал амжилттай байгуулагдах эрин юм. Гэвч та нар дэлхий дээр байгаа цагт, хүмүүсийн газар дээрх цуглаан “чуулган” хэмээгдсэн хэвээр үлдэнэ. Гэхдээ чуулганы гол чанар урьд нэгэнтээ байснаасаа ондоо болсон ба тэр нь амжилттай байгуулагдсан чуулган юм. Тиймээс Миний хаанчлал газар дээр хэдийн бууж ирсэн гэж Би хэлдэг. Хэн ч Миний үгийн уг үндсийг ухаарч чадахгүй, мөн үүнийг ярих Миний зорилгыг ч мэдэхгүй. Миний өнөөдөр ярих байдлаас та нар гэнэтийн их ухаарал авна. Зарим нь гашуунаар цурхиран уйлж магадгүй; зарим нь Миний ярьдаг арга замаас айж; зарим нь Миний үйлдэл нэг бүрийг харангаа хуучинсаг үзэл бодолтойгоо зууралдаж магадгүй; зарим нь тухайн үед Надад гомдол дургүйцлээ илэрхийлж, Намайг эсэргүүцэж байсандаа магад харамсана; Миний нэрийг хэзээ ч орхиогүй зарим нь сэхэж, нууцхан баярлан хөөрч магадгүй. Миний үгэнд аль эртнээс хагас үхлүүт болж, цөхөрч, гутран хэдийгээр Би илэрхийлэх маягаа өөрчилсөн ч гэсэн Миний хэлэх үгийг ойшоох зүрх сэтгэлгүй болтлоо “тарчилсан” хүмүүс байдаг байх; эсвэл нэгэн үе хүртэл хэзээ ч гомдоллож, хэзээ ч эргэлзэлгүй Надад үнэнчээр үйлчлээд өнөөдөр чөлөөлөлтийг олж аван, зүрх сэтгэлдээ Надад үгээр илэрхийлшгүй талархах хувьтай хүмүүс бас байж магад.

Дээрх бүх нөхцөл хүн бүрд янз бүрийн түвшинд хамаардаг. Гэхдээ өнгөрсөн үе бол өнгөрсөн үе, одоо үе хэдийн ирчихсэн болохоор цаашид өнгөрснийг үгүйлэн халаглах юм уу ирээдүйн тухай бодох хэрэггүй. Хүн мөртөө бодит байдлын эсрэг явж, аливааг Миний удирдамжийн дагуу хийдэггүй хэн ч бай сайнаар дуусахгүй, харин өөрсдөдөө л төвөг удна. Орчлон ертөнц дээр тохиолддог бүх зүйлээс эцсийн шийдвэрийг нь Би гаргадаггүй юу ч үгүй. Миний гарт оршдоггүй юм байна уу? Миний хэлсэн бүхэн биелдэг, хүмүүсийн дунд бодлыг минь өөрчилж чадах хэн байна вэ? Газар дээр байгуулсан Миний гэрээ байж болох уу? Миний төлөвлөгөөний ахиц дэвшилд юу ч саад болж чадахгүй; Би ажлаа цаг үргэлж хийж, бас удирдлагаа цаг ямагт төлөвлөдөг. Ямар хүн хөндлөнгөөс хуруугаа дүрж чадах юм бэ? Энэ бүхнийг биечлэн зохицуулсан нь Би биш гэж үү? Өнөөдрийн энэ ертөнцөд орох нь Миний төлөвлөгөө юм уу, Миний зөгнөж харснаас гаждаггүй; энэ бүгдийг Би аль эрт тодорхойлсон юм. Та нарын дундаас Миний төлөвлөгөөний энэ алхмыг хэн ойлгож чадах вэ? Миний ард Миний дуу хоолойг заавал сонсоно, Намайг үнэхээр хайрладаг хүн нэг бүр Миний сэнтийн өмнө заавал эргэж ирнэ.

1992 оны 2 дугаар сарын 20

2-Р БҮЛЭГ

Шинэ арга замд орохын хамтаар Миний ажилд шинэ алхмууд байх болно. Хаанчлалд байдагтай адилаар Би аливаа зүйлсийг бурханлаг чанараар дамжуулан шууд хийж, хамгийн нарийн хэсэг хүртэл няхуур байж, хүний санаа зорилгын ямар ч хольцгүйгээр замын алхам бүрийг хөтлөх болно. Дараах нь бодит хэрэгжүүлэлтийн замуудыг товч тойм юм: Бэрхшээл болон цэвэршүүлэлтээр дамжуулан тэд “ардууд” гэх цолыг хүртсэн, мөн Миний хаанчлалын ардууд болохоор Би тэднийг хатуу чанд шаардлагад барих ёстой ба үүний стандарт нь өмнөх үеийнхэнд зориулсан Миний ажлын арга барилаас илүү өндөр. Энэ нь зөвхөн үгийн бодит байдал байгаад зогсохгүй, үүнээс ч чухал нь хэрэгжүүлэлтийн бодит байдал юм. Үүнд эхлээд хүрэх ёстой. Бүх үг болон үйл хэргээрээ тэд хаанчлалын ардуудаас шаарддаг стандартад нийцэх ёстой ба Миний нэрийг шившиглэхээс зайлсхийхийн тулд аливаа гэмтнүүдийг нэн даруй зайлуулах ёстой. Гэхдээ, тодорхой харж чаддаггүй, ойлгож чаддаггүй мунхаг хүмүүс хамаарахгүй. Миний хаанчлалыг бүтээн байгуулахдаа Миний үгийг идэж, ууж, Миний мэргэн ухааныг ойлгож, Миний ажлаар дамжуулан баталгаа олоход анхаарал хандуул. Хэрвээ хүн Миний үгийг агуулдаг номоос өөр номд анхаарал хандуулдаг бол Би гарцаагүй тэднийг хүсэхгүй; ийм хүмүүс бол Намайг эсэргүүцдэг янхан юм. Элчийн хувиар хүн гэртээ хэтэрхий удаан суух ёсгүй. Хэрвээ тэгдэг бол Би тэр хүнийг хаяад, цаашид ашиглахгүй. Элчүүд гэртээ удаан байдаггүй учраас босгон байгуулагдахын тулд чуулганд удаан хугацааг

өнгөрүүлдэг. Элчүүд чуулганы хоёр цуглаан тутмын ядаж нэгд нь оролцох ёстой. Иймээс хамтран зүтгэгчдийн цуглаан нь (бүх элчийн цуглаан, бүх чуулганы удирдагчдын цуглаан, тодорхой мэдлэг ухаантай ариун хүмүүст зориулсан бүх цуглааныг оролцуулаад) тогтмол явагддаг болох ёстой. Та нарын ядаж зарим нь цуглаан болгонд оролцох ёстой ба элчүүд чуулганыг харж хандахад л анхаарах ёстой. Ариун хүмүүст өмнө нь тавьж байсан шаардлагууд одоо илүү гүн гүнзгий болсон. Намайг Өөрийн нэрийг гэрчлэхээс өмнө зөрчил үйлдсэн хүмүүсийн хувьд Надад өгсөн зориулалтаас нь үүдэн, туршсаныхаа дараа Би тэднийг мөн л ашиглана. Гэвч Миний гэрчлэлийн дараа дахин зөрчил үйлдсэн бөгөөд гэмшиж, шинээр эхлэхийн тулд зовж зүдрэхээр шийдсэн хүмүүсийн хувьд тийм хүмүүс зөвхөн чуулган дотор л үлдэнэ. Гэсэн ч тэд хайнга, дураараа байж болохгүй, харин бусдаас илүү биеэ барьж байх ёстой. Намайг үг хэлсний дараа өөрсдийн замыг засаж залруулдаггүй хүмүүсийн тухайд гэвэл Миний Сүнс тэднийг нэн даруй орхиод, чуулган Миний шүүлтийг гүйцэтгэх эрхтэй байж, тэднийг чуулганаас хөөх болно. Энэ нь гарцаагүй бөгөөд өөр бодож үзэх зүйл байхгүй. Хэрвээ хүн шалгалтын үеэр нуран унавал, өөрөөр хэлбэл, орхин явбал Намайг туршиж, чуулганд галзууран орох боломжийг Сатанд олгохоос зайлсхийхийн тулд хэн ч тэр хүнд анхаарал хандуулах ёсгүй. Энэ бол тийм хүнийг шүүх Миний шүүлт билээ. Орхин явсан хүнд зөв шударга бус хандаж, өөрсдийн сэтгэл хөдлөлдөө автан үйлдвээс явсан хүн байр сууриа алдаад зогсохгүй, мөн нөгөө хүн ч гэсэн Миний ардуудын дундаас хөөгдөнө. Элчүүдийн өөр нэг чиг үүрэг нь сайн мэдээг түгээхэд анхаарах явдал юм. Мэдээж ариун хүмүүс ч бас энэ ажлыг хийж чадна, гэхдээ тэд ийнхүү хийхдээ ухаалаг байж, төвөг удахаас татгалзах ёстой. Дээрх зүйлс нь хэрэгжүүлэлтийн одоогийн арга зам юм. Мөн сануулж хэлэхэд та нар өөрсдийн номлолыг илүү гүн гүнзгий болгоход анхаарлаа хандуулах ёстой, ингэснээр бүгд Миний үгийн бодит байдалд орж болох юм. Та нар Миний үгийг нарийн нягт дагаж, бүх хүнд тодорхой, хоёрдмол утгагүйгээр ойлгуулах ёстой. Энэ нь хамгийн чухал юм. Миний ардуудын дундаас урвах бодох өвөрлөдөг хүмүүс хөөгдөх ёстой ба Миний нэрийг шившиглэх вий гэсэндээ Миний гэрт удаан хугацаагаар үлдэхийг тэдэнд зөвшөөрөх ёсгүй.

1992 оны 2 дугаар сарын 21

3-Р БҮЛЭГ

Та нар Миний ард гэж нэрлэгдсэн болохоор юмс урьдынх шигээ байхаа больсон; та нар Миний Сүнсний айлдваруудыг сонсож, дуулгавартай даган, Миний ажлыг ойрхон дагах ёстой; Миний Сүнс болон Миний махбодыг салгаж болохгүй, учир нь Бид бол төрөлхөөсөө нэг агаад угаасаа салшгүй билээ. Сүнс болон хүнийг

салгаж, хүнийг юм уу эсвэл Сүнсийг анхаардаг хэн боловч хохирол амсаж, өөр ямар ч сонголтгүйгээр өөрсдийнхөө гашуун зовлонгийн аяганаас л уух болно. Сүнс болон хүнийг салшгүй нэгэн бүхэл гэж харж чаддаг хүмүүс л Миний талаар хангалттай мэдлэгтэй байдаг ба тэдний доторх амь аажмаар өөрчлөгдөнө. Ажлынхаа дараагийн алхмыг саад бартаагүй, төвөггүй урагшлуулахын тулд Би Өөрийн гэрт байгаа хүмүүсийг туршихдаа үгийн цэвэршүүлэлт хэрэглэж, Намайг дагадаг хүмүүсийг туршихдаа ажлын арга барил ашигладаг. Ийм нөхцөл байдалд тэд бүгд итгэл найдвараа алддаг гэж хэлж болно; хүмүүсийн хувьд бүгд сөрөг, идэвхгүй нөхцөл байдалтай байдаг ба бүхий л орон зай өөрчлөгдсөн мэт байдаг. Зарим хүн Тэнгэр, газрыг зүхдэг; зарим нь цөхөрсөндөө өөрсдийгөө хатамжлан, Миний үгийн туршилтыг хүлээн авдаг; зарим нь тэнгэр лүү харж, гүнзгий шүүрс алдан, дөнгөж төрсөн нярайн цаг бусын үхлээс болж хямарсан мэт нүдийг нь нулимс бүрхдэг; заримд нь бүр ингэж амьдрах ичгүүртэй санагддаг тул өөрсдийг нь удалгүй аваач гэж Бурханд залбирдаг; зарим нь хүндээр өвчлөөд хараахан ухаан ороогүй байгаа мэт бүхий л өдрийг мэл гайхан өнгөрөөдөг; зарим нь гомдоллосныхоо дараа сэмхэн явж оддог; зарим нь өөрсдийнхөө байгаа газраас Намайг магтсаар байдаг ч зарим талаар сөрөг хэвээр үлддэг. Өнөөдөр бүх зүйл илчлэгдэх үед Би өнгөрсний талаар дахин ярих хэрэггүй; илүү их ач холбогдолтой зүйл бол та нар өнөөдөр Миний өгсөн байр сууриас туйлын үнэнч хэвээр байж чаддаг байх ёстой, ингэснээр хийсэн бүхэн чинь Миний сайшаалд нийцэж, хэлдэг бүхэн чинь Миний гэгээрэл, гэрэлтүүлэлтийн үр дүн болж, эцэстээ амьдран харуулдаг зүйл чинь Миний дүр, бүхэлдээ Миний илэрхийлэл байх юм.

Миний үг хэдийд ч, хаана ч хэлэгдэж, илэрхийлэгддэг тул та нар ч бас цаг ямагт Миний өмнө өөрсдийгөө мэдэж байх ёстой. Учир нь, өнөөдөр бол эцсийн эцэст өнгөрсөн үетэй адилгүй бөгөөд цаашид чи хүссэн бүхнээ биелүүлж чадахгүй. Харин чи Миний үгийн удирдамж дор өөрийнхөө биеийг захирах чадвартай байх ёстой; чи Миний үгийг түшиг тулгуураа болгон ашиглах ёстой ба болчимгүй аашилж болохгүй. Чуулгануудын бодит хэрэгжүүлэлтийн бүх замыг Миний үгээс олж болно. Миний үгийн дагуу үйлддэггүй хүмүүс Миний Сүнсэнд шууд халддаг ба Би тэднийг устгана. Нэгэнт юмс өнөөдрийн ийм нөхцөл байдалд хүрсэн учраас та нар өнгөрсөн үеийн үйл хэрэг, үйлдэлдээ хэтэрхий их шаналж, харамсах хэрэггүй. Миний уужим сэтгэл далай тэнгис, тэнгэр мэт хязгааргүй—хүний чадвар болон Миний талаарх мэдлэгийг Би алган дээрээ тавьсан мэт мэддэг бус уу? Хүмүүсийн дундаас Миний гарт байдаггүй хэн байна вэ? Биеийн хэмжээ чинь хэр том болохыг Би огт мэддэггүй, үүнийг ердөө ч мэдэхгүй гэж чи бодож байна уу? Тийм байх боломжгүй! Тиймээс бүх хүнийг хамгийн их цөхөрч байхад, хүлээж чадахаа болиод, шинээр эхлэхийг хүсэх үед, юу болоод байгааг Надаас асуухыг хүсэх үед, зарим нь самуун явдалд умбаж, заримд нь бослого гаргах санаа төрж, зарим нь үнэнчээр үйлчлэл үзүүлж байх үед Би Өөрийн ардуудыг ариусгаж, шүүх шүүлтийн эриний хоёр дахь хэсгийг эхлүүлнэ. Өөрөөр хэлбэл, Би Өөрийн ардыг албан ёсоор сургаж эхлэн,

Надад сайхан гэрчлэл хийгээд зогсохгүй, түүнчлэн Миний төлөө Миний ардын суудлаас тулаанд сүрлэг ялалт байгуулах боломжийг та нарт олгоно.

Миний ардууд цаг ямагт Сатаны зальхай явуулгаас сэрэмжилж, Миний төлөө Миний гэрийн үүдийг хамгаалах ёстой; Сатаны урхинд унахаас сэргийлэхийн тулд бие биеэ дэмжиж, нэг нэгийгээ хангаж чаддаг байх ёстой ба Сатаны занганд унавал харамсахад хэтэрхий оройтсон байх болно. Яагаад Би та нарыг ийнхүү яаран сургаж байна вэ? Яагаад Би та нарт сүнсний ертөнцийн бодит баримтыг хэлж өгдөг вэ? Яагаад Би та нарт ахин дахин сануулж, захидаг вэ? Та нар энэ талаар ер нь бодож үзэж байсан уу? Бодож тунгаагаад ер нь тодорхой ойлгосон уу? Тиймээс та нар өнгөрсөн үеийн суурин дээр үндэслэн өөрсдийгөө боловсруулаад зогсохгүй, түүнчлэн өнөөдрийн үгийн удирдамж дор өөрсдийн доторх хольцыг арилган, Миний үг болгоныг сүнсэн дотроо үндэслүүлж, цэцэглүүлж, бүр ч чухал нь илүү их жимс гаргах хэрэгтэй. Учир нь Миний шаарддаг зүйл бол гоёмсог цэцэгс биш, харин элбэг дэлбэг үр жимс буюу мууддаггүй үр жимс юм. Миний үгийн жинхэнэ утгыг ойлгов уу? Хүлэмжин дэх цэцэгс одод шиг тоо томшгүй олон агаад бахдан биширсэн олны сэтгэлийг татдаг хэдий ч хатаж гандмагцаа Сатаны овжин явуулга шиг салбайж навсайдаг ба хэн ч тэдгээрийг сонирхдоггүй. Харин салхинд үлээгдэн, наранд шарагдаж, Надад гэрчлэл хийдэг бүх хүн гоёмсог сайхнаар цэцэглэдэггүй хэдий ч цэцэгс нь хагдармагц жимсэлдэг, учир нь Би тэгэхийг шаарддаг билээ. Эдгээр үгийг хэлэх үед минь та нар хэр ихийг ойлгож байна вэ? Цэцэгс гандаж, үр жимс ургамагц, мөн энэ бүх жимс Миний таашаалын төлөө өгөгдмөгц Би газар дээрх бүх ажлаа төгсгөж, Өөрийн мэргэн ухааны биелэлтийг эдэлж эхэлнэ!

1992 оны 2 дугаар сарын 22

4-Р БҮЛЭГ

Миний өмнө үйлчилдэг Миний бүх ард өнгөрснөө эргэн санах хэрэгтэй: Намайг хайрлах та нарын хайр хольцтой юу? Надад өгсөн үнэнч байдал чинь цэвэр, чин сэтгэлийнх байсан уу? Миний талаарх та нарын мэдлэг үнэн байсан уу? Та нарын зүрх сэтгэлд Би хэр их зай эзэлж байсан бэ? Би зүрх сэтгэлийг чинь бүхэлд нь дүүргэж байсан уу? Миний үг та нарын дотор хэр ихийг биелүүлсэн бэ? Намайг бүү мэхэл! Эдгээр зүйл Надад тов тодорхой байдаг! Өнөөдөр, Миний авралын дуу хоолой айлдаж байхад Намайг хайрлах та нарын хайр жаахан нэмэгдсэн үү? Надад үнэнч байдлын чинь зарим хэсэг цэвэр болсон уу? Миний талаарх та нарын мэдлэг гүнзгийрсэн үү? Өнгөрсөн үеийн магтаал сайшаал өнөөдрийн мэдлэгийн чинь бат бэх суурийг тавьсан уу? Та нарын хэр ихийг Миний Сүнс эзэлдэг вэ? Миний дүр та нарын дотор хэр их зай эзэлдэг вэ? Миний айлдварууд та нарын дотор зорьсондоо хүрсэн үү? Өөрсдийн ичгүүрийг нуух газаргүй гэдгээ та нар үнэхээр мэдэрч байна

уу? Та нар Миний ардууд байх эрхгүй гэдэгтээ үнэхээр итгэдэг үү? Хэрвээ та нар дээрх асуултуудыг огт анзаарахгүй байгаа бол булингартай усанд загасчилж, зүгээр л тоо бүрдүүлж байгааг чинь энэ нь харуулах бөгөөд Миний урьдчилан тогтоосон цагт чи гарцаагүй таягдан хаягдаж, хоёр дахь удаагаа ёроолгүй нүхэнд унана. Энэ бол Миний анхааруулсан үг бөгөөд үүнийг хөнгөн хуумгай авч үзсэн хүмүүс Миний шүүлтэд өртөж, товлосон цагт гай зовлонтой тулгарна. Тийм биз дээ? Үүнийг тайлбарлахын тулд Би бас л жишээ татах хэрэгтэй гэж үү? Та нарыг үлгэр загвараар хангахын тулд Би илүү тодорхой ярих ёстой юу? Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл олон хүн Миний үгэнд дуулгаваргүй хандаж, улмаар Миний дахин сэргээлтийн урсгалаас зайлуулагдаж, таягдан хаягдсан; эцэст нь тэдний бие мөхөж, сүнс нь Үхэгсдийн орон руу хаягдсан бөгөөд өнөөдөр ч гэсэн тэд хатуу шийтгэлд өртсөөр байгаа. Олон хүн Миний үгийг дагасан боловч тэд Миний гэгээрэл, гэрэлтүүлэлтийн эсрэг явсан, тиймээс Надад өшиглүүлж, Сатаны эзэмшил дор орж, Намайг эсэргүүцдэг хүмүүс болсон. (Өнөөдөр Намайг шууд эсэргүүцдэг бүх хүн Миний үгийн өнгөн талыг л дуулгавартай дагаж, Миний үгийн мөн чанарт дуулгаваргүй ханддаг.) Мөн өчигдрийн хэлсэн үгийг минь хальт сонсож, урьдын “хог новштой” зууралдаж, эдүгээгийн “үр шимийг” эрхэмлэдэггүй олон хүн байсан. Энэ хүмүүс Сатанд олзлогдоод зогсохгүй, мөнхийн нүгэлтнүүд болж, Миний дайснууд болсон ба тэд Намайг шууд эсэргүүцдэг. Тийм хүмүүс бол Миний уур хилэнгийн оргил дахь Миний шүүлтийн байнууд бөгөөд өнөөдөр ч гэсэн тэд сохор хэвээр байж, харанхуй гяндан дотор байсаар байна (өөрөөр хэлбэл, тийм хүмүүс нь Сатанаар удирдуулсан илжирч, хөшсөн үхдлүүд юм; Би тэдний нүдийг халхалсан учраас тэднийг сохор гэж хэлдэг). Та нарт лавлагаа болох жишээ татаж өгсөн нь дээр, тэгвэл та нар үүнээс суралцаж чадна:

Паулын талаар дурдахад л та нар түүний түүхийг болон түүний талаарх алдаа мадагтай, бодит байдалд нийцэхгүй зарим үйл явдлыг санана. Тэр багаасаа эцэг эхээрээ заалгаж, Миний амийг хүлээн авсан бөгөөд Миний урьдчилан тогтоосны үр дүнд Миний шаарддаг хэв чанарыг эзэмшсэн байв. 19 насандаа тэр амийн тухай янз бүрийн ном уншсан; тиймээс хэв чанараасаа үүдэн, мөн Миний гэгээрэл, гэрэлтүүлэлтээс үүдэн тэрээр сүнслэг асуудлуудын талаар нэлээд мэдлэгтэй ярьж чаддагаар зогсохгүй, мөн Миний санаа зорилгыг ойлгож чаддаг байсан гэдгийг Би нэг бүрчлэн ярих шаардлагагүй. Мэдээж, энэ нь дотоод ба гадаад хүчин зүйлсийн хослолыг хасаагүй. Гэсэн хэдий ч өөрийн авьяас билгээс болж тэр үргэлж хэлэмгий, онгироо байсан нь түүний нэг өө байсан юм. Үүний үр дүнд, тэргүүн тэнгэрэлчийг шууд төлөөлдөг хэсэг болох дуулгаваргүй байдлынхаа улмаас эхний удаад махан биетэй болоход минь Намайг сөрөх гэж тэр бүх чадлаараа хичээсэн. Тэр Миний үгийг мэддэггүй хүмүүсийн нэг байсан бөгөөд түүний зүрх сэтгэл дэх Миний байр аль хэдийн алга болсон байлаа. Тийм хүмүүс Миний бурханлаг чанарыг шууд эсэргүүцэн Надад цохигддог ба бүр эцэстээ л өвдөг сөхрөн, нүглээ наманчилдаг. Үүнээс хойш, Би түүний давуу талуудыг ашигласны дараа—өөрөөр

хэлбэл, хэсэг хугацаанд Миний төлөө ажилласныхаа дараа тэр хуучин замдаа дахиж орсон бөгөөд хэдийгээр Миний үгэнд шууд дуулгаваргүй хандаагүй ч Миний дотоод удирдамж, гэгээрэлд дуулгаваргүй хандаж, улмаар урьд нь түүний хийсэн бүхэн талаар болсон; өөрөөр хэлбэл, түүний ярьж байсан алдрын титэм хоосон үг, өөрийнх нь төсөөллийн үр дүн болсон, учир нь өнөөдөр ч гэсэн тэр Миний гав гинжин дунд Миний шүүлтэд захирагдаж байдаг.

Намайг эсэргүүцдэг (Миний махан биеийг эсэргүүцээд зогсохгүй хамгийн чухал нь Миний үгийг, Миний Сүнсийг, өөрөөр хэлбэл, Миний бурханлаг чанарыг эсэргүүцдэг) хэн боловч Миний шүүлтийг махан биедээ хүртэнэ гэдгийг дээрх жишээнээс харж болно. Миний Сүнс чамайг орхиход чи доошоо чигээрээ унаж, шууд Үхэгсдийн орон руу бууна. Хэдийгээр махан бие чинь газар дэлхий дээр байвч чи сэтгэцийн өвчнөөр шаналж байгаа хүнтэй адилхан: Чи эрүүл ухаанаа алдаж, тэр даруйдаа үхдэл болсон мэт санагддаг болохоор махан биеийг чинь нэн даруй эцэс болгооч гэж Надаас гуйдаг. Сүнс эзэмшсэн та нарын ихэнх нь эдгээр нөхцөл байдлын талаар гүнзгий ойлгодог бөгөөд Би цааш нь дэлгэрүүлэн ярих хэрэггүй. Урьд нь Намайг хэвийн хүн чанараар ажиллаж байхад ихэнх хүмүүс Миний уур хилэн, сүр жавхлантай аль хэдийн хүчээ үзсэн ба Миний мэргэн ухаан, зан чанарыг аль хэдийн бага зэрэг мэдсэн. Өнөөдөр Би бурханлаг чанараар шууд ярьж, үйлддэг бөгөөд Миний уур хилэн, шүүлтийг өөрсдийн нүдээр харах зарим хүн бас бий; түүнчлэн шүүлтийн эрин үеийн хоёр дахь хэсгийн үндсэн ажил бол Өөрийн бүх ардад Өөрийн махан биеэр хийх үйл хэргийг шууд мэдэгдэж, та нарт бүгдэд нь Өөрийн зан чанарыг шууд харуулах явдал юм. Гэвч Би махбодод байгаа учраас та нарын сул талуудыг харгалзан үздэг. Та нар өөрсдийн сүнс, сэтгэл, биеийг тоглоом шиг үзэж, тэдгээрийг Сатанд хайхрамжгүйгээр хээвнэг зориулахгүй гэж Би найдаж байна. Өөртөө байгаа бүхнийг нандигнаж, үүнд тоглоом шиг хандахгүй байх нь дээр бөгөөд учир нь ийм зүйлс та нарын хувь заяатай холбоотой. Та нар Миний үгийн жинхэнэ утгыг үнэхээр ойлгож чадах уу? Миний чин үнэнч сэтгэлд хайхрамжтай хандах чадвар та нарт үнэхээр бий юү?

Та нар тэнгэрт байдаг ерөөлтэй адил газар дээрх ерөөлийг минь эдлэхэд бэлэн байна уу? Та нар Миний тухай ойлголт, Миний үгийн таашаал, Миний талаарх мэдлэгийг амьдралынхаа хамгийн үнэ цэнтэй, утга учиртай зүйлс хэмээн үзэхэд бэлэн үү? Та нар өөрсдийн хэтийн ирээдүйг бодолгүйгээр Надад бүрэн захирагдаж үнэхээр чадах уу? Та нар өөрсдийгөө хонь адилаар Надаар нядлуулж, Надаар удирдуулж үнэхээр чадах уу? Тийм зүйлсийг биелүүлж чадах хүн та нарын дунд байна уу? Надаар хүлээн зөвшөөрөгдөж, Миний амлалтыг хүлээн авсан бүх хүн Миний ерөөлийг хүртдэг хүмүүс юм гэж үү? Эдгээр үгээс та нар ямар нэг зүйлийг ойлгов уу? Хэрвээ Би та нарыг туршвал та нар өөрсдийгөө Миний эрхшээлд үнэхээр орхиж, эдгээр шалгалтын дунд Миний санаа зорилгыг эрж хайн, Миний зүрх сэтгэлийг ухамсарлаж чадах уу? Би чамайг сэтгэл хөдөлгөм олон үг хэлж, эсвэл олон сонирхолтой түүх ярьж чаддаг байгаасай гэж хүсэхгүй; харин Надад

сайн гэрчлэл хийж, бодит байдал руу бүрэн дүүрэн, гүн гүнзгий орж чаддаг байхыг Би чамаас шаардаж байна. Хэрвээ Би шууд яриагүй бол чи эргэн тойрныхоо бүх зүйлийг хаяж, өөрийгөө Надаар ашиглуулахыг зөвшөөрч чадах байсан уу? Энэ нь Миний шаарддаг бодитой байдал биш гэж үү? Миний үгийн утга учрыг хэн ухаарч чадах вэ? Гэсэн ч цаашид эргэлзээнд автахгүй байж, өөрсдийн оролтод санаачилгатай байж, Миний үгийн мөн чанарыг ухаарахыг Би та нараас шаардаж байна. Энэ нь Миний үгийг буруу ойлгож, Миний утгыг ойлгохгүй байж, улмаар Миний захиргааны зарлигийг зөрчихөөс та нарыг сэргийлнэ. Миний үгээс та нарын төлөө гэсэн Миний санаа зорилгыг та нар ухаарна гэж Би найдаж байна. Өөрсдийн хэтийн ирээдүйн талаар дахин бүү бод, мөн бүх зүйл дээр Бурханы зохион байгуулалтад захирагдана гэж Миний өмнө шийдвэр гаргасан мэт үйлд. Миний гэр дотор зогсож байгаа тэр бүх хүн чадах чинээгээрээ аль болох ихийг хийх ёстой; чи газар дээрх Миний ажлын сүүлчийн хэсгийн төлөө хамгийн сайнаа өргөн барих ёстой. Чи ийм зүйлсийг хэрэгжүүлэхэд үнэхээр бэлэн байна уу?

1992 оны 2 дугаар сарын 23

5-Р БҮЛЭГ

Миний Сүнсний дуу хоолой бол бүхий л зан чанарын минь илэрхийлэл билээ. Та нар ойлгож байна уу? Энэ зүйлийг тодорхой мэдэхгүй байх нь Намайг шууд эсэргүүцэхтэй адилхан. Энд оршдог ач холбогдлыг та нар үнэхээр харсан уу? Би та нар дээр хэр их хичээл чармайлт, хэр их эрч хүч зарлагадсаныг та нар үнэхээр мэддэг үү? Та нар өөрсдийн хийсэн зүйлийг, мөн Миний өмнө яаж авирлаж байснаа ил харуулж үнэхээр зүрхэлнэ гэж үү? Бас та нар Миний өмнө өөрсдийгөө Миний ардууд гэж нэрлэх зүрх зоригтой байдаг—та нарт ямар ч ичгүүр сонжуур байхгүй, эрүүл ухаан бүр ч байхгүй! Эрт орой хэзээ нэгэн цагт, та нар шиг хүмүүс Миний гэрээс таягдан хаягдана! Миний төлөө гэрчлэлд зогссон гэж бодоод Надад бүү ахарх! Энэ нь хүн төрөлхтний хийж чадах зүйл мөн үү? Санаархал болон зорилгоос чинь юу ч үлдээгүй бол чи аль хэдийн өөр замаар орчихсон байх байлаа. Хүний зүрх сэтгэл хэр ихийг агуулж чадахыг Би мэдэхгүй гэж бодож байна уу? Энэ цагаас эхлээд чи бүх зүйл дээр хэрэгжүүлэлтийн бодит байдал руу орох ёстой; урьдынхтайгаа адилаар зүгээр дэмий чалчаад юунд ч хүрэхгүй. Урьд нь та нараас ихэнх нь Миний дээвэр дор сорон мөлжиж дөнгөсөн; өнөөдөр та нар бат зогсож чадаж байгаа нь бүхэлдээ Миний үгийн хатуу ширүүнээс болж байгаа юм. Намайг санаан зоргоор, ямар ч зорилгогүй ярьдаг гэж бодож байна уу? Боломжгүй хэрэг! Би бүх зүйлийг өндрөөс харж, бүх зүйлийг өндрөөс ноёрхдог. Үүний адилаар Би Өөрийн авралыг газар дээр хэрэгжүүлсэн. Би Өөрийнхөө нууц газраас хүмүүсийн хөдөлгөөн бүрийг, хэлдэг хийдэг бүхнийг хараагүй байх мөч гэж хэзээ ч байдаггүй.

Хүмүүс бол Миний хувьд нээлттэй ном: Би тэднийг бүгдийг нь хардаг, бас мэддэг. Нууц газар бол Миний орон байр бөгөөд тэнгэрийн уудам бүхэлдээ Миний хэвтдэг ор билээ. Сатаны хүчнүүд Надад хүрч чадахгүй, учир нь Би сүр жавхлан, зөвт байдал, шүүлтээр бялхаж байна. Үгээр илэрхийлэх аргагүй нууц Миний үгэнд оршдог. Намайг ярих үед сүнс чинь ухаан мэдрэлээ алдсанаас болж та нар ус руу дөнгөж шидэгдээд учраа олохгүй самгардсан шувуу шиг, эсвэл саяхан айж цочоод юугаа ч мэдэхгүй байгаа нялх хүүхэд шиг болдог. Нууц газар бол Миний орон байр гэж Би яагаад хэлдэг вэ? Миний үгийн илүү гүн утгыг чи мэдэх үү? Хүмүүсийн дотор Намайг мэдэх чадвартай хэн байна вэ? Хэн Намайг төрсөн эцэг, эхээ мэддэг шигээ мэдэх чадвартай вэ? Өөрийн орон байранд амрангаа Би анхааралтай ажигладаг: Газар дээрх бүх хүн өөрсдийнхөө хувь заяа, ирээдүйн төлөө үймэн бужигнаж, “дэлхийг тойрон аялж”, өөд уруугүй яаравчилдаг. Гэвч Миний хаанчлалыг байгуулахад зориулах эрч хүч ганцад нь ч байдаггүй, амьсгаа авах хэмжээний хүчин чармайлт ч байдаггүй. Би хүмүүсийг бүтээж, гай зовлонгоос олон удаа аварсан; гэвч, энэ хүмүүс бүгд ач тус мэддэггүй: Тэдний дундаас нэг нь ч Миний авралын бүх тохиолдлыг тоолж чаддаггүй. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөг хүртэл маш олон жил, олон зуун өнгөрсөн; Би маш олон гайхамшиг үзүүлж, маш олон удаа мэргэн ухаанаа харуулсан. Гэсэн ч, хүмүүс сэтгэцийн өвчтэй мэт солиотой, хөшүүн байдаг бөгөөд заримдаа бүр ойд тэнүүчилж яваа зэрлэг араатан шиг л Миний ажил хэрэгт анхаарал хандуулах өчүүхэн ч бодолгүй байдаг. Би хүмүүст олон удаа үхэх ял өгч, тэднийг үхүүлэхээр ялласан боловч Миний удирдлагын төлөвлөгөөг хэн ч өөрчилж чадахгүй. Тиймээс, Миний гарт хүмүүс өөрсдийн зууралддаг хуучин зүйлсийг илчилсээр байдаг. Өөрийн ажлын алхмуудаас үүдэн Би, доройтож, гажуудсан, балиар, бузар өнөр бүлд төрсөн та нарыг дахин нэгэнтээ аварсан.

Миний төлөвлөсөн ажил нэг ч хором зогсолгүй урагшилсаар байдаг. Хаанчлалын эрин үед орж, та нарыг Өөрийн ардууд болгон хаанчлалдаа оруулсан тул Би та нарт өөр шаардлагууд тавина; өөрөөр хэлбэл, энэхүү эринийг захирахдаа баримтлах үндсэн хуулийг Би та нарын өмнө тунхаглан зарлаж эхэлнэ:

Та нар Миний ардууд гэж нэрлэгддэг тул Миний нэрийг алдаршуулж чаддаг байх ёстой; өөрөөр хэлбэл, шалгалтын дунд гэрчлэлд зогс. Хэрвээ хэн нэгэн Намайг аргалж, Надаас үнэнийг нуух гэж оролдвол, эсвэл Миний араар шившигтэй үйл хийвэл тийм хүмүүс бүгд ялгаагүй Миний гэрээс хөөгдөж, зайлуулагдан, өөрсөдтэй нь харьцахыг минь хүлээнэ. Урьд нь Надад үнэнч бус, ачлалгүй байсан хүмүүс, мөн өнөөдөр Намайг ил тод шүүхээр дахин өндийн босдог хүмүүс ч бас Миний гэрээс хөөгдөнө. Миний ардууд ачаанд минь үргэлж анхаарал хандуулж, түүнчлэн үгийг минь мэдэхээр эрэлхийлэх ёстой. Ийм хүмүүсийг л Би гэгээрүүлэх бөгөөд тэд хэзээ ч гэсгээлт амсахгүйгээр, Миний удирдамж, гэгээрэл дор амьдрах нь гарцаагүй. Миний ачаанд анхаарал хандуулж чадалгүй, өөрсдийнхөө ирээдүйг төлөвлөхөд хамаг анхаарлаа төвлөрүүлдэг хүмүүс—өөрөөр хэлбэл, үйлдлээрээ Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгахаар зорихын оронд өглөг тусламж хайдаг

хүмүүс буюу гуйлгачин шиг энэ амьтдыг ашиглахаас Би эрс татгалзана, учир нь тэд төрсөн цагаасаа л Миний ачаанд анхаарал хандуулна гэж юу гэсэн үг болохыг огт мэдээгүй. Тэд бол хэвийн эрүүл ухаанаар дутмаг хүмүүс юм; ийм хүмүүс тархины “тэжээлийн дутагдлаас” болж зовж байгаа ба “шим тэжээл” авахын тулд гэртээ харих хэрэгтэй. Надад ийм хүмүүс ямар ч хэрэггүй. Миний ардуудын дундах хүн бүр, Намайг мэдэх явдлыг идэх, хувцаслах, унтахтай адил хүний хэзээ ч, ганц хором ч мартдаггүй зүйл шиг, эцэст нь хүртэл заавал биелүүлэх үүрэг гэж үзэх шаардлагатай, ингэснээр Намайг мэдэх гэдэг нь эцэстээ хоол идэхтэй адил, дадсан гараар амархан хийдэг зүйл болно. Миний хэлдэг үгийн тухайд бол, нэг бүрийг нь туйлын итгэлтэйгээр авч үзэн, бүрэн өөрийн болгох ёстой; хааш яаш, хагас дутуу арга хэмжээ байж болохгүй. Миний үгэнд анхаарал хандуулдаггүй хэнийг ч Намайг шууд эсэргүүцэж байна гэж үзнэ; Миний үгийг иддэггүй, эсвэл тэдгээрийг мэдэхээр эрэлхийлдэггүй хэнийг ч Надад анхаарал хандуулахгүй байна гэж үзэх ба Миний гэрийн хаалгаар шууд шүүрдэж гаргана. Яагаад гэвэл, урьд нь Миний хэлсэнчлэн Миний хүсдэг зүйл бол асар олон тооны хүн биш, харин онцгой сайн чанар юм. Зуун хүнээс нэг нь л Миний үгээр дамжуулан Намайг мэдэж чаддаг бол Би энэ ганцхан хүнийг гэгээрүүлж, гэрэлтүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэхийн тулд бусдыг нь бүгдийг хаяхад бэлэн байх болно. Олон тооны хүмүүс дангаараа Намайг илтгэж, Намайг амьдран харуулж чадна гэдэг үнэн байх албагүй гэдгийг эндээс харж болно. Миний хүсдэг зүйл бол (хэдийгээр үр нь дүүрэн биш байж болох ч) улаан буудай бөгөөд (хэдий үр нь бахадмаар боловсорсон байсан ч) үрийн сүүл биш юм. Эрж хайхыг анхаардаггүй, харин хөшүүн хойрго байдлаар авирладаг хүмүүсийн тухайд гэвэл, тэд өөрсдөө явах ёстой; тэд Миний нэрд гутамшиг авчирсаар байх вий гэсэндээ Би тэднийг дахиж харахыг хүсдэггүй. Өөрийн ардуудаас шаарддаг зүйлийн тухайд бол, Би одоохондоо эдгээр журам дээр түр зогсоод, нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамааран дараагийн арга хэмжээ авахаар хүлээнэ.

Урьд нь, хүмүүсийн дийлэнх нь Намайг мэргэн ухааны Бурхан Өөрөө бөгөөд хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг яг тэр Бурхан мөн гэж бодсон; гэвч энэ нь—ердөө өнгөцхөн яриа байсан юм. Хэрвээ хүмүүс үнэхээр Намайг мэддэг байсан бол дүгнэлт хийх гэж яарахгүй, харин оронд нь Миний үгээр дамжуулан Намайг мэдэхээр хичээсээр байх байлаа. Тэр Миний үйл хэргийг үнэхээр харсан үе шатанд очих үедээ л Намайг Ухаалаг, Гайхалтай гэж нэрлэхүйц болох байв. Миний тухай мэдлэг чинь хэтэрхий нимгэн. Эрин үеүдийн турш тун олон хүн, маш олон жилийн турш Надад үйлчилж, Миний үйл хэргийг хараад Миний талаар үнэхээр ямар нэг зүйл мэддэг болсон. Энэ шалтгааны улмаас, тэд үргэлж Надад дуулгавартай зүрх сэтгэлээр хандсан ба Миний мөрийг эрж хайхад хэцүү байдгаас болоод Намайг эсэргүүцэх санаа зорилго өвөрлөж огт зүрхлээгүй. Энэ хүмүүсийн дунд Миний удирдамж байгаагүй бол тэд хөнгөн хуумгай үйлдэж зүрхлэхгүй байх байв. Тиймээс олон жилийн туршлагаараа тэд эцэст нь Миний тухай мэдлэгийн нэг хэсгийг

ерөнхийлөн дүгнэж, Намайг Ухаалаг, Гайхалтай агаад Зөвлөгч гэж дуудан, Миний үг давхар иртэй илд мэт, мөн Миний үйл хэрэг агуу, гайхалтай, гайхмаар бөгөөд Би сүр жавхлангаар хувцаслаж, Миний мэргэн ухаан огторгуйгаас өндөрт хүрдэг гэх мэтийн ойлголтыг хэлсэн. Харин өнөөдөр Миний талаарх та нарын мэдлэг тэдний тавьсан суурин дээр л үндэслэдэг тул та нарын дийлэнх нь тэдний хэлсэн үгийг тоть шиг л давтаж байна. Миний талаарх мэдлэг чинь хэчнээн нимгэн гэдгийг, мөн “боловсрол” чинь хэчнээн тааруухан болохыг Би харгалзаж үзсэн учраас л маш их гэсгээлтээс та нарыг хэлтрүүлсэн юм. Тэгсэн ч гэсэн та нарын дийлэнх олонх нь бас л өөрсдийгөө мэддэггүй, эсвэл өөрсдийн үйл хэргээр Миний хүслийг аль хэдийн биелүүлчихсэн ба энэ шалтгааны улмаас шүүлтээс мултарсан гэж боддог; эсвэл махбод болсныхоо дараа Би хүн төрөлхтний үйлдлийг огт мэдэхээ больчихсон ба энэ шалтгаанаас үүдэн та нар ч бас гэсгээлтээс мултарсан гэж боддог; эсвэл та нарын итгэдэг Бурхан орчлон ертөнцийн уудам зайд оршин байдаггүй гэж боддог тул та нар Бурханы мэдэх явдлыг өөрсдийн биелүүлэх ёстой үүрэг хэмээн зүрх сэтгэлдээ хадгалахын оронд завтай цагтаа хийх ажил болгон доогуур тавиад, Бурханд итгэх итгэлийг, дэмий өнгөрөөх байсан цагаа нөхцөөх арга зам болгон ашигладаг. Хэрвээ Би эрдэм чадал, эрүүл ухаан, гүн ойлголт дутуу дулимгийг чинь харгалзан үзээгүй бол та нар бүгдээрээ Миний гэсгээлтийн дунд мөхөж, амьдралаас арчигдах байлаа. Гэсэн хэдий ч, газар дээрх Миний ажил дуусах хүртэл Би хүн төрөлхтөнд хүлээцтэй ханддаг хэвээр байна. Энэ нь та бүгдийн мэдэх ёстой зүйл бөгөөд сайн, мууг бүү хольж хутга.

1992 оны 2 дугаар сарын 25

6-Р БҮЛЭГ

Сүнсний доторх хэрэг явдалд, чи нарийн мэдрэмжтэй байх хэрэгтэй; Миний үгийг хичээнгүйлэн анхаарах ёстой. Миний Сүнс ба Миний бие махбодыг, Миний үг ба Миний бие махбодыг хуваагдашгүй нэгэн бүхэл мэт харах тэрхүү төлөв байдлыг зорих хэрэгтэй, ингэснээр бүх хүн Миний өмнө Намайг сэтгэл хангалуун байлгаж чадна. Би орчлон ертөнцийг Өөрийн хөлөөр туулж, харцаа хаяа хязгаарт нь бэлчээж, хүний туршлагын чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай амтыг амтлан бүх хүний дунд алхсан, гэвч үнэндээ хүн Намайг хэзээ ч таниагүй, Намайг хаа сайгүй явахад ч анзаараагүй. Учир нь Би чимээгүй байж, ямар ч ер бусын үйл хийгээгүй, иймээс үнэндээ Намайг хэн ч, хэзээ ч хараагүй. Юмс одоо урьдынх шигээ байхаа больсон: Би бүтээлийн эхлэлээс хойш хүний хэзээ ч үзээгүй зүйлсийг хийж, эрин үеүдийн туршид хүний хэзээ ч сонсож байгаагүй үгийг хэлэх гэж байна, учир нь Би бүх хүн төрөлхтнөөс махбод дахь Намайг мэддэг болооч гэж хүсдэг. Энэ бол Миний удирдлагын алхмууд бөгөөд энэ талаарх өчүүхэн төдий ч таамаг хүмүүст байдаггүй.

Би энэ талаар илэн далангүй ярьсан ч хүний оюун санаа нь мунгинасаар байдаг болохоор түүнд нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй. Хүний адгийн дорд байдал үүнд оршдог, тийм биз? Энэ бол Миний засахыг хүсдэг яг тэр зүйл юм, үгүй гэж үү? Энэ бүх он жилүүдэд Би хүн дээр юу ч хийгээгүй; энэ бүх он жилүүдэд Миний махбод болсон биетэй шууд холбоотой байсан хүмүүс хүртэл Миний бурханлаг чанараас шууд гарах дуу хоолойг хэзээ ч сонсоогүй. Иймээс Миний талаарх мэдлэг хүмүүст дутмаг байх нь гарцаагүй, гэхдээ эрин үеүдийн туршид энэ нэг зүйл хүн төрөлхтний Намайг гэх хайранд дангаараа нөлөөлөөгүй. Одоо харин Би та нарт гайхамшигт, тайлагдашгүй ажил тоолшгүй олныг авчирч, бас олон үг хэлсэн. Гэтэл иймэрхүү нөхцөл байдалд ч гэсэн маш олон хүн Намайг нүүрэн дээр минь эсэргүүцэж байна. Би чамд цөөн хэдэн жишээ дурдъя:

Чи Миний санаа зорилгыг ухаарч, амийг мэдрэх гээд өдөр бүр тодорхойгүй Бурханд залбирдаг. Гэхдээ Миний үг яг бууж ирэхэд чи тэдгээрийг өөрөөр хардаг: Чи Миний үг болон Миний Сүнсийг хуваагдашгүй нэгэн зүйл гэж үздэг боловч Над шиг хүн ийм үг хэлэх чадваргүй, харин ч энэ нь Миний Сүнсний олгосон үр дүн юм хэмээн бодож хүнийг нь хөсөр хаядаг. Энэ мэт нөхцөл байдлын тухай чи яаж мэдэх юм бэ? Чи Миний үгэнд тодорхой хэмжээгээр итгэдэг ч Миний өмссөн махбодын тухайд их бага хэмжээгээр өөрийн гэсэн үзэл тээж, түүнийгээ өдрөөс өдөрт лавшруулан бодож, “Тэр яагаад аливааг ингэж хийдэг юм бэ? Энэ Бурханаас ирдэг юм гэж үү? Байж боломгүй юм! Миний бодлоор, Тэр надтай бараг адилхан, эгэл, жирийн л хүн” гэж хэлдэг. Дахин хэлэхэд, чи ийм нөхцөл байдлыг хэрхэн тайлбарлах вэ?

Миний дээр хэлсэн зүйлийн тухайд, та нарын дунд ийм үзлээр зэвсэглээгүй хүн байна уу? Үүнийг эзэмшдэггүй хүн байна уу? Чи үүнийг яг л өөрийн нэг өмч шиг зуурчихаад, энэ бүх хугацаанд хаях дургүй байсан мэт харагдаж байна. Тэр ч бүү хэл, чи идэвхтэй хүчин чармайлт гаргахыг бүр ч хүсээгүй; харин Намайг биечлэн ажил хийхийг хүлээдэг. Үнэнийг хэлэхэд, Намайг эрж хайлгүйгээр амар хялбар мэдэж авсан нэг ч хүн байхгүй. Үнэн хэрэгтээ, Би та нарт өнгөц үгээр сургамж номлодог юм биш, учир нь чамд лавлагаа болгох гэж Би өөр өнцгөөс жишээ татаж чадна:

Петрийг дурдмагц хүн бүр магтан шагширч, Бурханыг гурвантаа үгүйсгэсэн, түүнчлэн Сатанд үйлчилж, улмаар Бурханыг туршсан, гэвч эцэстээ Түүний төлөө загалмайд уруу харж цовдлогдсон гэх зэрэг Петрийн тухай энэ бүх түүхийг тэр дороо санацгаадаг. Петр Намайг хэрхэн мэдэж авсныг, мөн түүний эцсийн үр дүн ямар байсан талаар одоо та нарт өгүүлэх нь маш чухал гэж Би үзэж байна. Петр гэгч энэ хүн гойд сайн хэв чанартай хүн байсан, гэхдээ түүний нөхцөл байдал Паулынхаас өөр байлаа. Түүний эцэг, эх Намайг хавчдаг, Сатанд эзэмдүүлсэн чөтгөрүүдэд харьяалагддаг байсан, энэ шалтгааны улмаас тэд Петрт замыг дамжуулсан гэж хэлж болохгүй юм. Цэцэн цэлмэг, төрөлхийн оюун билэгтэй Петрийг эцэг эх нь бага балчраас нь хайрладаг байжээ; харин өсөж том болсныхоо дараа тэр тэдний дайсан болсон, учир нь тэр үргэлж Намайг мэдэхээр эрэлхийлдэг

байсан ба энэ нь түүнийг эцэг эхийгээ орхиход хүргэсэн. Яагаад гэвэл, юуны өмнө тэнгэр, газар, бүх зүйл Төгс Хүчитийн гарт байдаг, бүх эерэг зүйл Бурханаас эхтэй ба Сатаны ямар ч боловсруулалтаар дамжилгүй Түүнээс шууд ирдэг гэдэгт тэр итгэдэг байсан юм. Товойлгогч болон үйлчлэх эцэг эхийнх нь сөрөг жишээ байснаар энэ нь түүнийг Миний хайр, энэрлийг илүү амархан таних боломжтой болгож, улмаар Намайг эрж хайх хүслийг нь улам бадраасан юм. Тэр зөвхөн Миний үгийг идэж, уухад их анхааралд зогсоогүй, Миний санаа зорилгыг ухаарахад бүр ч их анхаарал хандуулсан бөгөөд сүнсэндээ үргэлж гярхай, сүйхээтэй байхын тулд өөрийн бодолд байнга хашир, болгоомжтой байсан, иймд хийсэн бүхэндээ Миний тааллыг хүртэж чадсан юм. Жирийн амьдралдаа тэр бүтэлгүйтлийн занганд унахаас машид айж, хүчин чармайлтаа нэмэхэд өөртөө түлхэц өгөхийн тулд, урьд өмнө бүтэлгүйтсэн хүмүүсээс сургамж авахад онцгой анхаарч байв. Мөн эрин үеүдийн туршид Бурханыг хайрлаж байсан бүх хүний итгэл болон хайрыг өөрийн болгоход сайтар анхаарчээ. Ийм байдлаар тэр өөрийнхөө өсөх үйл явцыг зөвхөн сөрөг талууд дээр төдийгүй, бүр ч чухал нь Миний өмнө Намайг хамгийн сайн мэдэх нэгэн хүн болж чадталаа эерэг талууд дээр хурдасгасан юм. Ийм ч учраас, тэрээр байгаа бүхнээ Миний гарт атгуулж, бүр идэх, өмсөх, унтахдаа ч юм уу ер нь хаана ч байхдаа өөрийнхөө эзэн байхаа больж, харин бүх зүйл дээр Намайг сэтгэл хангалуун байлгасны үндсэн дээр Миний өгөөмөр хишгийг эдэлсэн гэдгийг төсөөлөхөд хэцүү биш. Би түүнийг олон ч удаа шалгалтад оруулж, энэ нь мэдээж хэрэг түүнийг хагас үхлүүт болгож орхисон, гэвч энэ олон зуун шалгалтын дунд ч тэр Надад итгэх итгэлээ хэзээ ч алдаж, урам хугараагүй. Өөрийг нь хэдийн хаячихсан гэж Намайг хэлэхэд ч тэрээр цөхрөөгүй, харин Намайг бодитой байдлаар, урьдын хэрэгжүүлэлтийн зарчимд нийцэлтэйгээр үргэлжлүүлэн хайрласан. Намайг түүнд ингэж хэлэх үед хэдий тэр Намайг хайрладаг байсан ч Би түүнийг сайшаагаагүй, харин эцэстээ түүнийг Сатаны гарт хаях байсан. Махан биед нь хүрээгүй, зөвхөн үг хэрэглэн явуулсан эдгээр шалгалтын дунд ч тэр Надад залбирсаар л байсан: “Өө, Бурхан минь! Тэнгэр газар хийгээд үй олон зүйлийн дунд Төгс Хүчит Таны гарт эс багтах хүн, бүтээл, эсвэл аливаа зүйл байна уу? Таныг надад өршөөл үзүүлэхийг хүсэх үед, зүрх сэтгэл минь Таны өршөөлд машид баясдаг; Та надад шүүлт хийхийг хүсэх үед, хэдий би үнэ цэнгүй байж мэдэх ч Таны үйл хэргийн гүн гүнзгий нууцыг улам их мэдэрдэг, учир нь Та эрх мэдэл, мэргэн ухаанаар дүүрэн билээ. Миний бие махбод хэдий зововч сүнсэндээ би тайтгардаг. Таны мэргэн ухаан, Таны үйл хэргийг би хэрхэн шагшин магтахгүй байх билээ? Таныг мэдэж авсныхаа дараа үхэх байсан ч би хэзээд бэлэн, дуртай байх болно. Өө, Төгс Хүчит Нэгэн минь! Та Өөрийгөө надад харуулахыг үнэхээр хүсэхгүй байгаа биш биз дээ? Таны шүүлтийг би үнэхээр хүлээн авах үнэ цэнгүй биш биз дээ? Таны харахыг хүсэхгүй байгаа зүйл надад байгаа юм болов уу?” Ийм төрлийн шалгалт дунд Петр хэдийгээр Миний санааг яг таг ухаарч чадаагүй боловч Надад ашиглагдах нь (зөвхөн Миний шүүлтийг хүлээн авч, ингэснээр хүмүүс Миний сүр

жавхлан, уур хилэнг үзэх байсан ч бай) нэр төр, хувийн алдрын хэрэг гэж үзсэн нь илэрхий бөгөөд шалгалтад орсондоо ердөө гутраагүй юм. Миний өмнө үнэнч байсан тул, бас өөрийг нь Би ерөөсөн учраас тэрээр хэдэн мянган жилийн турш хүн төрөлхтөнд үлгэр жишээ, дуурайл болсон билээ. Энэ нь чухамдаа та нарын дагавал зохих үлгэр жишээ биш гэж үү? Энэ удаа Намайг Петрийн талаар яагаад ийм урт зүйл ярьсныг та нар ойлгохыг хичээж, сайтар бодох хэрэгтэй. Энэ нь та нарын биеэ авч явах зарчим болох ёстой.

Хэдийгээр Намайг мэддэг маш цөөн хүн байдаг ч, үүнээс болж Би Өөрийн уурыг хүнд гаргахгүй, учир нь хүмүүс маш олон дутагдалтай тул Миний хүссэн түвшинд хүрнэ гэдэг тэдэнд хэцүү. Тиймээс Би өнөөдрийг хүртэл мянга мянган жилийн турш хүнийг өршөөсөөр ирсэн. Гэхдээ Миний өршөөлөөс болж та нар өөрсдийгөө өөгшүүлэх гэж яарахгүй гэдэгт Би найдаж байна; харин ч Петрээр дамжуулан та нар Намайг мэдэж авч, Намайг эрж хайж, Петрийн бүх түүхээр дамжуулан урьд хожид байгаагүй илчлэлийг хүлээн авч, өмнө нь хүний хүрч байгаагүй түвшинд ийм маягаар хүрэх ёстой. Орчлон ертөнц болон хязгааргүй уудам огторгуй даяар, тэнгэр, газар дахь бүх зүйл, газар дээрх тоо томшгүй олон зүйл, тэнгэр дэх үй олон зүйл нэг бүрчлэн Миний ажлын сүүлийн үе шатны төлөө бүх хүч чадлаа зориулж байна. Та нар Сатаны хүчээр ийш тийш жолоодуулж, хөндлөнгийн ажиглагчид болж үлдэхийг хүсэхгүй байлгүй дээ? Хүмүүсийн зүрх сэтгэл дэх Миний талаарх мэдлэгийг Сатан байнга залгиж, шүдээ хавиран, сарвуугаа сарвайлгаж, сүүлчийн амь тэмцсэн тулаандаа ордог. Энэ мөчид та нар түүний зальжин ов мэхэнд олзлогдохыг хүсэж байна уу? Миний ажлын сүүлийн үе шат дуусах мөчид өөрийнхөө амьдралыг сүйрүүлэхийг хүсэж байна уу? Мэдээж та нар Намайг өршөөл энэрлээ дахиад нэг удаа хүртээнэ гэж хүлээсээр байгаа юм биш биз дээ? Намайг мэдэхээр эрж хайх нь хамгийн чухал зүйл, гэхдээ та нар бодит хэрэгжүүлэлтэд анхаарал хандуулахаа умартах ёсгүй. Та нар Миний удирдамжид захирагдаж, өөрсдийн хүсэл тэмүүлэл, санаа зорилгод автахаа болино гэж найдсандаа Би нарийн ойлголтыг шууд Өөрийнхөө үгээр та нарт илчилж байна.

1992 оны 2 дугаар сарын 27

7-Р БҮЛЭГ

Барууны бүх салбар Миний дуу хоолойг сонсох ёстой:

Өнгөрсөн үед та нар Надад үнэнч байсан уу? Та нар онц гойд зөвлөмжийн үгийг минь сонссон уу? Та нарт бүдэг бадаг, тодорхойгүй биш, бодит найдвар бий юү? Хүний үнэнч байдал, хайр, итгэл—Надаас ирдэг зүйлээс өөр юу ч байхгүй, Миний өгдөг зүйлээс өөр юу ч үгүй. Миний ардууд аа, Миний үгийг сонсохдоо та нар Миний хүслийг ойлгодог уу? Миний зүрх сэтгэлийг хардаг уу? Урьд нь үйлчлэлийн зам

дээр байхдаа та нар аз эз, өсөлт уналттай тулгаран, доош унаж, бүр Надаас ч урвах хүртлээ аюулд орж байсан хэр нь Би хором бүрд та нарыг байнга аварч байсан гэдгийг та нар мэдсэн үү? Хором бүрд Би та нарыг дуудаж, аврахын тулд ямагт Өөрийн дуу хоолойгоор айлдаж байсныг мэдсэн үү? Та нар хэдэн удаа Сатаны торонд унав? Хэдэн удаа та нар хүмүүсийн урхинд орооцолдсон бэ? Түүнчлэн та нар хэр олон удаа биеэ барьж чадалгүй өөр хоорондоо эцэс төгсгөлгүй зөрчилдөөнд орж байсан бэ? Хэр олон удаа та нарын бие Миний гэрт, харин зүрх сэтгэл чинь хаа нэгтээ байсан бэ? Гэсэн хэдий ч та нарыг дэмжихийн тулд Би маш олон удаа авралын гараа сунгасан, Би та нарын дунд маш олон удаа өршөөлийн үрийг цацсан. Зовлонгийн дараах өрөвдмөөр байдлыг чинь Би маш олон удаа харж тэвчээгүй; маш олон удаа… Та нар үүнийг мэдэх үү?

Гэвч өнөөдөр Миний халамж доор та нар эцэстээ бүх бэрхшээлийг даван туулж, Би та нартай хамт баярлан хөөрдөг; энэ бол Миний мэргэн ухааны биелэлт юм. Гэхдээ, үүнийг сайн сана! Хэн унаж, харин та нар хүчтэй хэвээр үлдсэн бэ? Та нарын дундаас хэн нь сул дорой мөчийг хэзээ ч үзэлгүй хүчтэй байсан юм бэ? Хүмүүсийн дундаас хэн нь Надаас ирээгүй ерөөлийг эдэлсэн бэ? Хэн нь Надаас ирээгүй золгүй явдлыг амссан бэ? Намайг хайрладаг хүмүүс бүгд зөвхөн ерөөл хүлээн авдаг гэж үү? Намайг хайрлаж чадалгүй, харин ч эсэргүүцсэн учраас Иовд золгүй явдал тохиолдсон юм гэж үү? Паул Намайг үнэхээр хайрлаж чаддаг учраас Миний дэргэд Надад үнэнч үйлчилж чадсан юм гэж үү? Та нар хэдийгээр Миний гэрчлэлийг бат мөрддөг байж магадгүй боловч та нарын дундаас хэний гэрчлэл нь шижир алт шиг, ямар ч хольцгүй байж чадах вэ? Хүний үнэнч байдал жинхэнэ байж чадах уу? Би хэнээс ч, хэзээ ч ихийг шаардаагүй учраас та нарын гэрчлэл Надад таашаал авчирч байгаа нь “үнэнч байдалтай” чинь зөрчилддөггүй. Миний төлөвлөгөөний анхдагч санаа зорилгын дагуу байсан бол та нар бүгд “гологдол бүтээгдэхүүн”—стандартад нийцэхгүй байх байсан. Энэ нь “өршөөлийн үр цацах” талаар Миний ярьсан зүйл биш гэж үү? Та нарын хардаг зүйл Миний аврал уу?

Та нар бүгдээрээ эргэн санах хэрэгтэй: Миний гэрт эргэн ирснээсээ хойш, өөрийнхөө ашиг, алдагдлыг эргэцүүлэхгүйгээр, Петрийн нэгэн адил Намайг мэдэж авдаг хүн байна уу? Та нар Библийн өнгөн талыг ягштал цээжилчихсэн боловч үүний мөн чанараас ямар нэг зүйлийг өөрийн болгосон уу? Тэгсэн ч гэсэн өөрийгөө үнэхээр тавьж явуулахаас татгалзан “эд хөрөнгөтэйгөө” зууралдсаар байна. Намайг айлдах үед, та нартай нүүр тулан ярилцах үед Миний илчилсэн амийн үгийг хүлээн авахын тулд хаалттай хуйлмал номоо доош тавьсан хүн та нарын дунд хэн байна? Та нар Миний үгийг ойшоодоггүй, эрхэмлэдэг ч үгүй. Харин өөрсдийн байр суурийг хадгалахын тулд дайснуудаа буудах гэж Миний үгсийг пулемёт мэт ашигладаг; Намайг мэдэхийн тулд Миний шүүлтийг хүлээн авъя гэж та нар өчүүхэн төдий ч хичээдэггүй. Та нар бүгд хэн нэгэн рүү зэвсэг чиглүүлдэг ба бүгд “хувиа хичээдэггүй”, нөхцөл байдал бүрд “бусдын талаар боддог”. Энэ чинь та нарын өчигдөр хийж байсан зүйл биш гэж үү? Бас өнөөдөр? Та нарын “үнэнч байдал”

хэдхэн оноогоор өсөж, та нар бүгд бага зэрэг хашир сууж, бага зэрэг төлөвшсөн; үүнээс болж Надаас айх та нарын “айдас” ямар нэг байдлаар ихэссэн ба хэн ч “хөнгөмсөг авирладаггүй”. Яагаад та нар үргэлж идэвхгүй байдалд оршдог юм бэ? Яагаад та нарын хаанаас ч эерэг тал нь ерөөсөө олддоггүй юм бэ? Өө, Миний ардууд аа! Өнгөрсөн үе аль хэдийн өнгөрсөн; та нар цаашид үүнтэй зууралдах ёсгүй. Өчигдөр чи бат зогссон бол өнөөдөр Надад чин үнэнч байдлаа өгөх ёстой; түүнчлэн, маргааш Миний төлөө сайн гэрчлэл хийх ёстой бөгөөд ирээдүйд Миний ерөөлийг өвлөж авна. Энэ бол та нарын ойлгох ёстой зүйл билээ.

Хэдийгээр Би та нарын өмнө байхгүй ч гэсэн Миний Сүнс та нарт гарцаагүй нигүүлсэл хүртээнэ. Та нар Миний ерөөлийг нандигнаж, үүний улмаас өөрсдийгөө мэдэж авч чадна хэмээн Би найдаж байна. Үүнийг өөрийн хөрөнгө гэж бүү үз; үүний оронд та нар өөрсдөдөө дутагдаж байгаа зүйлийг Миний үгээс аван дүүргэж, үүнээс өөрийнхөө эерэг элементүүдийг гаргаж авах ёстой. Энэ бол та нарт өгч буй Миний захиас юм!

1992 оны 2 дугаар сарын 28

8-Р БҮЛЭГ

Миний илчлэлүүд оргилдоо хүрэх үед, мөн Миний шүүлт төгсгөлдөө очих үед энэ нь Миний бүх ард илчлэгдэж, бүрэн төгс болгуулах цаг байх болно. Миний санаа зорилготой нийцдэг, Надаар ашиглуулахад тохирдог хүмүүсийг зогсолтгүй хайхдаа Би орчлон ертөнцийн бүх булан тохойгоор аялдаг. Хэн өндийн босож, Надтай хамтран ажиллаж чадах вэ? Намайг гэсэн хүмүүсийн хайр өчүүхэн бөгөөд Надад итгэх итгэл нь ч бас өрөвдмөөр жаахан. Хэрвээ Би Өөрийн үгийн гол цохилтыг хүмүүсийн сул тал руу чиглүүлээгүй бол тэд бардамнаж, дэгсдүүлэн, газар дэлхийн хэрэг явдлын талаар анддаггүй, бүгдийг мэддэг мэтээр номчирхож, хэрээс хэтэрсэн онолуудыг зохиох байлаа. Урьд нь Надад “үнэнч” байсан хүмүүсээс, мөн өнөөдөр Миний өмнө “бат зогсдог” хүмүүсээс хэн бардамнан ярьсаар байж зүрхэлдэг вэ? Хэн өөрсдийн хэтийн ирээдүйд нууцхан баясдаггүй вэ? Хүмүүсийг шууд илчлээгүй байх үед минь тэд нуугдах газаргүй болж, ичсэндээ шаналж байсан. Хэрвээ Би өөр байдлаар ярьсан бол хэчнээн илүү дор байх байсан бэ? Хүмүүст бүр ч их өртэй санагдах байсан ба өөрсдийг нь юу ч эмчилж чадахгүй гэж бодоод, бүгдээрээ идэвхгүй байдалдаа ягштал баригдах байсан. Хүмүүс итгэл найдвараа алдах үед хаанчлалын ёслолын буудлага албан ёсоор тасхийдэг нь хүмүүсийн хэлснээр “долоо дахин эрчимжсэн Сүнс ажиллаж эхлэх цаг” юм. Өөрөөр хэлбэл, энэ нь хаанчлалын амьдрал албан ёсоор газар дээр эхэлдэг үе; Миний бурханлаг чанар (уураг тархиар “боловсруулагдалгүйгээр”) шууд ажиллахаар гарч ирдэг үе юм. Бүх хүн завгүй яаравчлан, бүгдээрээ сэргэж, зүүднээсээ сэрээд,

сэрэнгүүтээ тийм нөхцөл байдалд байгаагаа мэдээд мэл гайхаж байгаа мэт санагддаг. Урьд нь Би чуулган байгуулах талаар ихээхэн ярьсан; Би олон нууцыг илчилсэн боловч тэр ажил оргилдоо хүрэх үедээ гэнэтхэн төгссөн. Гэхдээ хаанчлалыг байгуулах нь өөр. Сүнсний ертөнц дэх тулаан эцсийн үе шатандаа хүрэх үед л Би газар дээрх ажлаа шинээр эхлүүлдэг. Өөрөөр хэлбэл, бүх хүн ухарч няцахын ирмэг дээр байх үед л Би Өөрийн шинэ ажлыг албан ёсоор эхэлж, өрнүүлдэг. Хаанчлал байгуулах, чуулган байгуулах хоёрын ялгаа гэвэл, чуулганыг байгуулахдаа Би бурханлаг чанараар удирдуулсан хүн чанараар ажилласан; Би хүмүүсийн хуучин уг чанартай шууд харьцаж, тэдний муухай төрхийг шууд илчилж, мөн чанарыг нь ил болгосон. Үүний үр дүнд, энэ суурин дээр тэд өөрсдийгөө мэдэж авч, улмаар зүрх сэтгэлдээ болон үгээрээ үнэмшсэн. Хаанчлалыг байгуулахдаа Би Өөрийн бурханлаг чанараар шууд ажилладаг ба Миний үгийг мэдсэний үндсэн дээр Надад юу байгаа, Би юу болохыг мэдэх боломжийг бүх хүнд олгон, эцэст нь бие махбодтой болсон Өөрийгөө тэдэнд мэдүүлдэг. Тийнхүү тодорхойгүй Бурханы хойноос хөөцөлдөх хүн төрөлхтний эрэл хайгуулыг төгсгөж, хүний зүрх сэтгэлд тэнгэр дэх Бурханы эзэлдэг байрыг үгүй болгодог; өөрөөр хэлбэл, Би бие махбодтой байх зуураа хийдэг үйл хэргээ хүмүүст мэдэгддэг ба ийнхүү Би газар дээр байх хугацаагаа дуусгана.

Хаанчлалыг байгуулах нь сүнсний ертөнц рүү шууд чиглэдэг. Өөрөөр хэлбэл, сүнсний ертөнцийн тулаан Миний бүх ардын дунд шууд ил болдог бөгөөд зөвхөн чуулганд ч төдийгүй ялангуяа Хаанчлалын эрин үед хүн бүр байнга тулалдаж байгаа гэдгийг энэ нь хангалттай харуулдаг. Тэд махан биетэй хэр нь сүнсний ертөнц шууд илчлэгдэж, сүнсний ертөнцийн амьдралтай холбогддог. Тиймээс, та нар үнэнч байж эхлэх үедээ Миний ажлын дараагийн хэсэгт зохих ёсоор бэлдэх ёстой. Та нар зүрх сэтгэлээ бүхэлд нь өгөх ёстой; тэр үед л Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чадна. Урьд нь чуулганд юу тохиолдсоныг Би огт тоодоггүй; өнөөдөр энэ нь хаанчлалд байна. Миний төлөвлөгөөнд Сатан алхам бүрийг үргэлж өсгий даран дагасаар ирсэн ба Миний мэргэн ухааны товойлгогчийн хувиар Миний анхдагч төлөвлөгөөг тасалдуулах арга зам олох гэж үргэлж оролдсоор ирсэн. Гэхдээ түүний зальхай явуулгад Би автаж болно гэж үү? Тэнгэр, газар дээр буй бүх зүйл Надад үйлчилдэг; Сатаны зальхай явуулга өөр байж чадна гэж үү? Яг энд Миний мэргэн ухаан огтлолцдог; энэ нь яг нарийндаа Миний үйл хэргийн гайхалтай байдал бөгөөд Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө хэрэгждэг зарчим юм. Хаанчлалыг байгуулах эринд Би Сатаны зальхай явуулгаас мөн л зайлсхийдэггүй, харин хийх ёстой ажлаа үргэлжлүүлэн хийдэг. Орчлон ертөнц болон бүх зүйлийн дундаас Би Сатаны үйл хэргийг Өөрийн товойлгогч болгон сонгосон. Энэ нь Миний мэргэн ухааны илрэл биш гэж үү? Миний ажлын гайхалтай байдал яг энэ биш гэж үү? Хаанчлалын эрин үед ороход тэнгэр, газар дахь бүх зүйл бүрмөсөн өөрчлөгдөж, тэмдэглэн баярладаг. Та нар ч гэсэн адилхан бус уу? Зүрх сэтгэл зөгийн балны амтгүй хэн байна вэ? Зүрх сэтгэл нь баяр хөөрөөр бялхдаггүй хэн

байна вэ? Баяр бахдалтайгаар бүжиглэдэггүй хэн байна вэ? Магтаалын үг хэлдэггүй хэн байна вэ?

Миний ярьсан, хэлсэн дээрх бүх зүйлийн зорилго, эх үүсвэрийг та нар ухаарч байна уу, үгүй юү? Хэрвээ Би ингэж асуугаагүй бол ихэнх хүмүүс Намайг зүгээр л дэмий чалчиж байна гэж бодоод, Миний үгийн эх сурвалжийг олж мэдэж чадахгүй байх байлаа. Хэрвээ та нар анхааралтай тунгаан бодвол тэдгээрийн ач холбогдлыг мэдэх болно. Тэдгээрийг анхааралтай уншсан чинь дээр: Миний үгийн аль нь чамд ашиг тусгүй байна? Аль нь чиний амийг өсгөхийн төлөө биш байна? Аль нь сүнсний ертөнцийн бодит байдлын талаар хэлэхгүй байна? Ихэнх хүмүүс Миний үгийг ямар ч холбоосгүй, утга учиргүй, мөн тайлбар, тайллаар дутмаг гэж боддог. Миний үг үнэхээр тийм хийсвэр, ойлгохын аргагүй гэж үү? Та нар Миний үгэнд үнэхээр захирагддаг уу? Та нар Миний үгийг үнэхээр хүлээн авдаг уу? Та нар тэдгээрийг тоглоом шиг үздэг бус уу? Чи тэдгээрийг үзэшгүй муухай дүр төрхөө далдлах хувцас болгон ашигладаг бус уу? Энэхүү өргөн уудам дэлхийд хэн өөрийн биеэр Надад шалгуулсан бэ? Хэн Миний Сүнсний үгийг биечлэн сонссон бэ? Маш олон хүн харанхуйд тэмтчиж, хайдаг; маш олон хүн гай зовлон дунд залбирдаг; маш олон хүн өлсөж, дааран, горьдлоготойгоор хардаг; мөн маш олон хүн Сатанд хүлэгддэг; гэсэн ч маш олон хүн хаашаа хандахаа мэддэггүй, маш олон хүн аз жаргалынхаа дунд Надаас урваж, маш олон хүн талархдаггүй ба маш олон хүн Сатаны зальхай явуулгад үнэнч байдаг. Та нарын дундаас хэн Иов бэ? Хэн Петр вэ? Яагаад Би Иовыг ахин дахин дурддаг вэ? Яагаад Би Петрийн тухай маш олон удаа хэлсэн бэ? Та нарын төлөөх итгэл найдварыг минь та нар ер нь ухамсарласан уу? Та нар ийм зүйлсийг тунгаан бодоход илүү их цаг зарцуулах ёстой.

Петр олон жилийн турш Надад үнэнч байсан мөртөө хэзээ ч үглэж гоншигноогүй, гомдоллоогүй; Иов хүртэл түүнтэй эн зэрэгцэж чадаагүй бөгөөд эрин үеүдийн туршид ариун хүмүүс ч бүгдээрээ Петрээс хамаагүй дор байсан. Тэр Намайг мэдэхээр эрэлхийлээд зогсоогүй, мөн Сатаныг зальхай явуулгаа хэрэгжүүлж байх үеэр Намайг мэдэж авсан юм. Энэ нь Петрийг Надад олон жил үйлчилж, үргэлж Миний хүсэлтэй нийцэхэд хүргэсэн ба иймээс тэр хэзээ ч Сатанд ашиглуулж байгаагүй. Петр Иовын итгэлээс сургамж авсан атлаа Иовын дутагдлыг ч бас тодорхой ойлгож байв. Хэдийгээр Иов агуу итгэлтэй байсан ч түүнд сүнсний ертөнц дэх хэрэг явдлын талаарх мэдлэг дутмаг байсан тул тэр бодит байдалтай зохицоогүй олон үг хэлсэн; Иовын мэдлэг өнгөц байсан бөгөөд төгс болж чадахгүй байсан гэдгийг энэ нь харуулдаг. Тиймээс Петр сүнсний мэдрэмжийг олж авахад үргэлж төвлөрч, сүнсний ертөнцийн хөдөлгөөнийг ажиглахад анхаарлаа үргэлж хандуулдаг байжээ. Үүний үр дүнд, тэр Миний хүслээс ямар нэг зүйл олж мэдэж чадсанаар үл барам, бас Сатаны зальхай явуулгаас жаахан ойлгосон. Үүнээс үүдэн Миний талаарх түүний мэдлэг эрин үеүдийн туршид байсан өөр хэнийхээс ч илүү их байлаа.

Хэрэв хүмүүс Намайг мэдэхийг хүсвэл сүнсэн дотроо анхааралтай эргэцүүлэх ёстой гэдгийг Петрийн туршлагаас харахад хэцүү биш. Гаднаа Надад тодорхой

хэмжээгээр “зориулахыг” Би чамаас шаарддаггүй; энэ бол хоёрдогч ач холбогдолтой зүйл. Хэрэв чи Намайг мэдэхгүй бол чиний ярьдаг бүх итгэл, хайр, үнэнч байдал зүгээр л хоосон санаа төдий; тэдгээр нь дэмий яриа бөгөөд чи Миний өмнө асар их бардамнан сайрхдаг ч өөрийгөө мэддэггүй хүн болох нь лавтай. Тиймээс чи дахин нэг удаа Сатанд урхидуулаад өөрийгөө чөлөөлж чадахгүй байх болно; чи мөхлийн хүү, сүйрлийн бай болно. Гэхдээ хэрвээ чи Миний үгэнд хүйтэн хөндий, хайхрамжгүй ханддаг бол Намайг эргэлзээгүй эсэргүүцэж байна. Энэ бол бодит баримт бөгөөд Миний гэсгээсэн олон янзын сүнснүүдийг сүнсний ертөнцийн үүд хаалгаар сайтар харсан чинь дээр. Миний үгтэй тулгараад тэднээс аль нь Миний үгэнд идэвхгүй, хайхрамжгүй, үл зөвшөөрсөн байдлаар хандаагүй вэ? Аль нь Миний үгэнд эрээ цээргүй хандаагүй вэ? Аль нь Миний үгээс өө сэв олох гэж оролдоогүй вэ? Тэднээс аль нь өөрсдийгөө “хамгаалахын” тулд Миний үгийг “хамгаалах зэвсэг” болгон ашиглаагүй вэ? Тэд Миний үгийн агуулгыг Намайг мэдэх арга зам болгон ашиглаагүй, харин зүгээр л тоглодог тоглоом шиг хэрэглэсэн. Ингэснээрээ тэд Намайг шууд эсэргүүцэж байсан бус уу? Миний үг хэн бэ? Миний Сүнс хэн бэ? Би та нарт маш олон удаа ийм асуулт тавьсан атал тэдгээрийн талаарх мэдлэг ухаан чинь ер нь илүү өндөр, тодорхой болсон уу? Та нар ер нь тэдгээрийг үнэхээр туулсан уу? Би та нарт дахин нэг удаа сануулъя: Хэрвээ та нар Миний үгийг мэддэггүй, хүлээн авдаггүй, хэрэгжүүлдэггүй бол Миний гэсгээлтийн бай болох нь гарцаагүй! Сатаны хохирогч болох нь гарцаагүй!

1992 оны 2 дугаар сарын 29

9-Р БҮЛЭГ

Чи Миний гэрийн хүмүүсийн дунд байдаг учраас, чи Миний хаанчлалд үнэнч учраас хийдэг бүхэндээ Миний шаарддаг стандартыг мөрдөх ёстой. Би чамайг хөвөгч үүл болгоод зогсохгүй, харин гялтганах цас болгож, мөн чанарыг нь, үүнээс ч илүүтэйгээр үнэ цэнийг нь эзэмшүүлдэг. Би ариун газраас ирсэн учраас нэр төдий, мөн чанаргүй бадамлянхуа цэцэгтэй адил биш, учир нь тэр ариун газраас биш, харин намаг балчгаас гардаг билээ. Шинэ тэнгэр газар дээр бууж, шинэ газар тэнгэр дээгүүр тархах үе бол Би албан ёсоор хүмүүсийн дунд ажилладаг яг тэр үе юм. Хүмүүсийн дундаас хэн Намайг мэдэх вэ? Миний ирэх мөчийг хэн харсан бэ? Би нэртэй байгаад зогсохгүй, бас мөн чанартай гэдгийг хэн харсан бэ? Би цагаан үүлсийг Өөрийн гараар арчин холдуулж, тэнгэрийг ойроос ажигладаг; Миний гараар зохицуулагддаггүй зүйл огторгуйд огт үгүй ба огторгуйн дор, Миний агуу үйл хэргийн хэрэгжилтэд өчүүхэн хувь нэмрээ оруулдаггүй ямар ч хүн байхгүй. Би газар дээрх хүмүүст яршигтай шаардлага тавьдаггүй, учир нь Би үргэлж бодитой Бурхан байсаар ирсэн ба Би бол хүмүүсийг бүтээсэн Төгс Хүчит бөгөөд тэднийг сайн

мэддэг билээ. Бүх хүн Төгс Хүчитийн нүдний өмнө байдаг. Газар дэлхийн хамгийн буйдхан өнцөг буланд байдаг хүмүүс хүртэл Миний Сүнсний шинжилтээс зайлсхийж яахан чадах билээ? Хүмүүс Миний Сүнсийг “мэддэг” боловч Миний Сүнсэнд халдсаар байдаг. Миний үг бүх хүний муухай царайг ил гаргаж, бүх хүний зүрх сэтгэлийн хамгийн гүний бодлуудыг ч ил гаргадаг бөгөөд газар дээрх хүн бүхэн Миний гэрэлд ил болж, Миний шинжилтийн дунд нуран унадаг. Гэхдээ унаж, бүтэлгүйтсэн хэр нь тэдний зүрх сэтгэл Надаас холдон явж зүрхэлдэггүй. Бүтээгдсэн зүйлсийн дунд Миний үйл хэргээс болоод Намайг хайрладаггүй хэн байна? Миний үгийн үр дүнд Намайг хүсэн эрмэлздэггүй хэн байна вэ? Миний хайраас болоод сэтгэл татагддаггүй хэн байна вэ? Сатан завхруулснаас болоод хүмүүс Миний шаардсан байдалд хүрч чадаагүй. Сатан цадиггүй аашлан галзуу мэт эзэрхэг байдаг эрин буюу Сатан хүний хамаг биеийг бохир заваанд хутгалдтал нь дэвсэлсэн цаг үе болох өнөөдөр битгий хэл, Миний шаарддаг хамгийн доод стандарт ч хүний санааг зовоодог. Хүмүүс доройтлынхоо уршгаар Миний зүрх сэтгэлийг анхаарч чадаагүй нь Надад уй гашуу авчраагүй гэж үү? Би Сатаныг өрөвддөг юм гэж үү? Миний хайр андуурсан юм гэж үү? Хүмүүс Надад дуулгаваргүй байхад Миний зүрх сэтгэл нууцхан уйлдаг; Намайг эсэргүүцэхэд нь Би тэднийг гэсгээдэг; тэд Надаар аврууллж, үхлээс дахин амилахад Би тэднийг дээд зэргээр халамжлан тэжээдэг; тэднийг Надад захирагдахад Миний зүрх сэтгэл амарч, тэнгэр, газар, бүх зүйлд асар их өөрчлөлт гарч байгааг тэр даруй мэдэрдэг. Хүмүүс Намайг магтахад Би баярлахгүй байж яаж чадах билээ? Тэд Намайг гэрчилж, Надаар авхуулахад Би алдаршихгүй байж яаж болох юм бэ? Хүмүүсийн хийдэг бүхнийг Би захирч, хангадаггүй гэж үү? Намайг чиглэл заавар өгөөгүй үед хүмүүс хойрго, хөдөлгөөнгүй болдог; түүнчлэн, Миний ар хударгаар тэд тэдгээр “магтууштай” бохир ажлыг эрхэлдэг. Өөрийгөө хувцасласан бие махбод минь чиний үйлдэл, зан авир, үг хэлний талаар юу ч мэдэхгүй гэж чи бодож байна уу? Олон жил Би салхи, бороог тэсвэрлэж, хүний ертөнцийн гашууныг ч мөн амссан; гэхдээ сайн эргэцүүлэн бодвол ямар ч их зовлон шаналал махан биетэй хүнийг Надад итгэж найдахаа болиход хүргэхгүй, ямар ч сайхан байдал махан биетэй хүнийг Надад хүйтэн хөндий, сэтгэлээр унаж, үл ойшоосон байдлаар хандахад хүргэж бүр ч чадахгүй. Намайг гэх хүний хайр үнэхээр зовлон шаналалгүй юм уу сайхан байдалгүй байхаар хязгаарлагддаг юм уу?

Өнөөдөр Би махан биед оршдог ба Өөрийн хийх ёстой ажлыг албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. Гэхдээ хүмүүс Миний Сүнсний дуу хоолойноос айдаг хэдий ч Миний Сүнсний мөн чанарын эсрэг явдаг. Бие махбодтой Намайг Миний үгээс мэдэх нь хүний хувьд хэчнээн хэцүү гэдгийг Би цааш нарийвчлан ярих хэрэггүй. Урьд нь хэлсэнчлэн Би хатуу шаардлага тавьдаггүй ба та нар Миний тухай бүрэн мэдлэг олж авах албагүй (учир нь хүмүүс дутуу дулимаг; энэ нь төрөлхийн нөхцөл байдал бөгөөд олдмол нөхцөлүүд нь үүнийг нөхөж чадахгүй) юм. Та нар бие махбодтой Миний хийсэн, хэлсэн бүхнийг л мэдэх хэрэгтэй. Миний шаардлагууд

хатуу биш тул та нар бүгдээрээ эдгээр үйл хэрэг, үгийг мэдэж авч, мөн биелүүлж чадна гэж Би найддаг. Та нар энэ бохир дэлхийд өөрсдийн хольцоос салах ёстой, энэ хоцрогдсон “хаадын гэр бүлд” ахиц дэвшил гаргахаар тэмүүлэх ёстой ба алгуурлах ёсгүй. Та нар өөрсдөдөө өчүүхэн төдий ч зөөлөн хандах ёсгүй. Ганц өдөрт юу айлдсаныг минь мэдэхийн тулд чи асар их цаг хугацаа, хичээл чармайлт зориулах ёстой бөгөөд Миний хэлсэн ганц ч гэсэн өгүүлбэрийг мэдэх нь насан туршийн туршлагатай тэнцэхүйц билээ. Миний хэлдэг үг бүдэг бадаг, хийсвэр биш; мөн хоосон яриа биш. Олон хүн Миний үгийг олж авахыг хүсдэг, гэвч Би тэднийг тоодоггүй; олон хүн Миний тос нүнжгээр ангаж цангадаг, гэвч Би тэдэнд жаахныг ч өгдөггүй; олон хүн Миний царайг харахыг хүсдэг, гэхдээ Би үүнийг үргэлж нуусан; олон хүн Миний дуу хоолойг анхааралтай сонсдог, гэвч Би нүдээ анин, толгойгоо гэдийлгээд, тэдний “хүсэл тэмүүлэлд” уярдаггүй; олон хүн Миний дуу хоолойн чимээнээс айдаг, гэхдээ Миний үг үргэлж дайрч довтолдог; олон хүн Миний царайг харахаас эмээдэг, гэвч тэднийг цохин унагахын тулд Би зориуд гарч ирдэг. Хүмүүс Миний царайг үнэхээр хэзээ ч хараагүй, Миний дуу хоолойг ч хэзээ ч үнэхээр сонсоогүй; учир нь тэд Намайг үнэхээр мэддэггүй билээ. Тэд Надад цохиулан унаж болох ч, Намайг орхиж магад хэдий ч, Миний гарт гэсгээгдэж магадгүй ч өөрсдийнх нь хийдэг бүхэн үнэхээр Миний зүрх сэтгэлийн дагуу юу гэдгийг бас л мэддэггүй ба Би яг хэнд зүрх сэтгэлээ илчилдгийг ч мэддэггүй. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл хэн ч Намайг үнэхээр мэдээгүй, эсвэл Намайг үнэхээр хараагүй ба хэдийгээр Би өнөөдөр махбод болсон ч та нар Намайг бас л мэддэггүй. Энэ нь бодит баримт биш гэж үү? Махбод дахь Миний үйлдлүүд болон зан чанараас багахныг ч гэсэн чи ер нь харсан уу?

Тэнгэрт Би налан суудаг ба тэнгэрийн доор Би амардаг. Надад оршин суудаг газар бий, мөн Өөрийн хүч чадлыг харуулдаг цаг Надад бий. Хэрвээ Би газар дээр байгаагүй бол, хэрвээ Би Өөрийгөө махбод дотор далдлаагүй бол, хэрвээ Би даруухан, нуугдмал байгаагүй бол тэнгэр, газар аль эрт өөрчлөгдчихсөн байх бус уу? Миний ардууд та нарыг Би аль хэдийн ашигласан байх бус уу? Гэсэн ч Миний үйлдэлд мэргэн ухаан байдаг ба Би хүмүүсийн худал хуурмаг байдлыг бүрэн мэддэг боловч тэдний үлгэр жишээг дагадаггүй, харин оронд нь тэдэнтэй солилцоо хийдэг. Сүнсний ертөнцөд Миний мэргэн ухаан шавхагдашгүй, махбод дахь Миний мэргэн ухаан мөнхийн. Миний үйл хэрэг ил болох яг тэр цаг энэ биш гэж үү? Өнөөгийн Хаанчлалын эрин үед хүртэл Би хүмүүсийг олон удаа уучилж, өршөөсөн. Би Өөрийн цагийг цаашид хойшлуулсаар байж үнэхээр болно гэж үү? Би хэврэг хүмүүст ямар нэг хэмжээгээр арай өршөөнгүй хандаж байсан хэдий боловч Миний ажил дуусчихвал хуучин ажлаа хийж Өөртөө бас төвөг удна гэж үү? Сатан буруутгахыг Би мэдсээр байж зөвшөөрнө гэж үү? Хүмүүс Миний үгийн бодит байдал болон Миний үгийн анхдагч утгыг хүлээн авахаас өөрийг хийх хэрэггүй. Миний үг энгийн ч гэсэн мөн чанартаа ярвигтай, учир нь та нар хэтэрхий өчүүхэн бөгөөд хэтэрхий хөшүүн болсон. Би махбодоор Өөрийн нууцыг шууд илчилж,

Өөрийн хүслийг ил болгох үед та нар анзаардаггүй; та нар дуу авиа сонсдог боловч утга учрыг нь ойлгодоггүй. Би уйтгар гунигт автдаг. Хэдийгээр Би махбодод байгаа боловч махбодын үйлчлэлийн ажлыг хийж чаддаггүй.

Махбод дахь Миний үйл хэргийг Миний үг, үйлдлүүдээс хэн мэдэж авсан бэ? Би Өөрийн нууцыг бичгээр илчилж, эсвэл чангаар ярихад хүмүүс бүгд мэл гайхдаг; тэд нам гүм болж, нүдээ аньдаг. Миний хэлж байгаа зүйл яагаад хүмүүст ойлгомжгүй байдаг юм бэ? Миний үг яагаад ийм ухан ойлгохын аргагүй байдаг юм бэ? Тэр Миний үйл хэрэгт яагаад нүдэн балай ханддаг юм бэ? Хэн Намайг харж, бас хэзээ ч мартахгүй байж чадах вэ? Хэн Миний дуу хоолойг сонсож, хажуугаараа өнгөрөөхгүй байж чадах вэ? Хэн Миний хүслийг мэдэрч, Миний зүрх сэтгэлд нийцэж чадах вэ? Би хүмүүсийн дунд амьдарч, явдаг; Би тэдний амьдралыг туулах гэж ирсэн—хэдийгээр бүх зүйлийг хүний төлөө бүтээснийхээ дараа тэдгээр нь сайн болсныг Би мэдэрсэн боловч хүмүүсийн дунд амьдраад Надад ямар ч баяр хөөр төрдөггүй, хүмүүсийн аз жаргалд Би баярладаггүй. Би тэднийг жигшиж, голоогүй, тэдэнд уян сэтгэлээр ч ханддаггүй—хүмүүс Намайг мэддэггүй учраас харанхуйд Миний царайг олж харахад хэцүү байдаг; мөн орилоон шуугиан дундаас Миний дуу хоолойг сонсоход бэрхшээлтэй байдаг бөгөөд Миний үгийг ялган таньж чаддаггүй. Тиймээс та нарын хийдэг бүхэн чинь өнгөн дээрээ Надад дуулгавартай байдаг ч зүрх сэтгэлдээ та нар Надад дуулгаваргүй хэвээр байдаг. Бүх хүн төрөлхтний хуучин уг чанар ийм байдаг гэж хэлж болно. Үүнээс ангид хэн байна вэ? Хэн Миний гэсгээлтийн бай биш вэ? Гэхдээ Миний хүлээцтэй байдал дор амьдардаггүй хэн байна? Хэрвээ хүмүүс бүгд Миний уур хилэнд устгагдах байсан бол тэнгэр газрыг бүтээсний минь утга учир юу байх вэ? Би нэгэнтээ олон хүнд анхааруулж, олон хүнд сануулсан, мөн олон хүнийг ил тод шүүсэн—энэ нь хүнийг шууд устгаснаас хамаагүй дээр биш гэж үү? Миний зорилго бол хүмүүсийг үхүүлэх биш, харин Өөрийнхөө шүүлтийн дунд бүх үйл хэргээ тэдэнд мэдэгдэх явдал юм. Та нар ёроолгүй нүхнээсээ дээш гарах үед, өөрөөр хэлбэл, өөрсдийгөө Миний шүүлтээс чөлөөлөх үед хувийн бодол, төлөвлөгөө чинь бүгд алга болж, бүх хүн Намайг сэтгэл хангалуун байлгахаар эрмэлзэнэ. Ингэвэл Би Өөрийн зорилгод хүрсэн байх бус уу?

1992 оны 3 дугаар сарын 1

10-Р БҮЛЭГ

Хаанчлалын эрин үе эцсийн эцэст өнгөрсөн үеэс ялгаатай. Энд хүн яаж авирладаг нь хамаагүй; харин ч Би ажлаа биечлэн гүйцэтгэхээр газар дээр бууж ирсэн бөгөөд энэ нь хүмүүсийн ухамсарлаж ч чадахгүй, биелүүлж ч чадахгүй зүйл юм. Дэлхий ертөнц бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл ийм олон жил үргэлж

чуулган байгуулах явдал л байсан боловч хаанчлалыг байгуулах талаар хэн ч, хэзээ ч сонсож байгаагүй. Хэдийгээр Би энэ бүхнийг Өөрийн амаар хэлж байгаа ч гэсэн үүний уг чанарыг мэддэг хүн байна уу? Би нэгэн удаа хүний ертөнцөд буун ирж, тэдний зовлон шаналлыг туулж, ажигласан хэдий ч бие махбодтой болсон Өөрийн зорилгыг гүйцэлдүүлээгүй. Хаанчлалыг байгуулж эхлэх үед Миний махбод болсон бие албан ёсоор үйлчлэлээ гүйцэтгэж эхэлдэг; өөрөөр хэлбэл, хаанчлалын Хаан Өөрийн дээд эрх мэдлийг албан ёсоор авдаг. Үүнээс үзэхэд, хаанчлал хүний ертөнцөд бууж ирсэн нь үгчилсэн илрэл төдийхөн биш, харин бодит байдал гэдэг нь илт юм; энэ бол “хэрэгжүүлэлтийн бодит байдлын” утга учрын нэг тал юм. Хүмүүс Миний үйлсээс ганцыг нь ч харсан удаагүй, Миний айлдваруудын нэгийг нь ч сонссон удаагүй. Тэр харсан байлаа ч гэсэн юу олж илрүүлэх байсан бэ? Миний ярихыг сонссон ч юу ойлгох байсан бэ? Дэлхий даяар хүн бүр Миний өршөөл, Миний хайр энэрэл дотор оршдог, гэвч бас бүх хүн Миний шүүлтэн дор, түүнчлэн Миний шалгалтан дор оршдог. Хүмүүс бүгдээрээ тодорхой хэмжээнд ялзарсан хэдий ч Би хүн төрөлхтнийг өршөөж, хайрласаар ирсэн; тэд бүгд Миний сэнтийн өмнө захирагдах үед ч Би тэдэнд гэсгээлт оноосон. Гэвч Миний илгээсэн зовлон, цэвэршүүлэлтийн дунд байдаггүй хүн бий юу? Маш олон хүн гэрлийн төлөө харанхуйд тэмтчин явж, маш олон хүн шалгалтаа гашуунаар тэмцэн туулж байна. Иов итгэлтэй байсан, гэсэн ч тэр өөртөө гарах гарц хайж байгаагүй гэж үү? Миний ардууд хэдийгээр шалгалтад бат зогсож чадах боловч чанга хэлэлгүйгээр зүрх сэтгэлдээ итгэдэг хүн бий юу? Хүмүүс зүрх сэтгэлдээ эргэлзэх зуураа өөрсдийн итгэлийг амаараа л хэлдэг биш гэж үү? Шалгалтад бат зогсож, шалгагдах үедээ үнэхээр дуулгавартай байсан нэг ч хүн үгүй. Энэ ертөнцийг харахаас зайлсхийхийн тулд Би Өөрийн нүүрийг халхлаагүй бол бүх хүн Миний дүрэлзсэн харцан дор нуран унах байсан, учир нь Би хүмүүсээс юу ч хүсдэггүй билээ.

Хаанчлалын ёслолын буудлага тасхийхэд тэр нь мөн долоон аянга нижигнэх үе бөгөөд энэхүү дуу чимээ тэнгэр, газрыг доргиож, дээд тэнгэрийг сэргээж, бүх хүний сэтгэлийн утсыг чичрүүлдэг. Хаанчлалын сүлд дуу агуу улаан лууны газар нутаг даяар албан ёсоор цуурайтан, агуу улаан лууны үндэстнийг устгаж, дараа нь Өөрийн хаанчлалыг байгуулсан гэдгийг минь нотолдог. Үүнээс ч чухал нь, Миний хаанчлал газар дэлхий дээр байгуулагддаг. Энэ мөчид Би дэлхийн улс орон бүхэнд Өөрийн тэнгэрэлч нарыг илгээж эхэлнэ, ингэснээр тэд Миний хөвгүүдийг, Миний ардуудыг хариулж болох юм; энэ нь бас Миний ажлын дараачийн алхмын шаардлагыг хангахын тулд байдаг. Гэхдээ Би тулалдахын тулд агуу улаан лууны цагираглан хэвтэж буй газарт биечлэн ирсэн. Бүх хүн махбод доторх Намайг мэдэж, махбодоос Миний үйл хэргийг харж чаддаг болох үед агуу улаан лууны ичээ үнс нурам болж, ул мөргүй арилна. Миний хаанчлалын ардуудын хувиар та нар агуу улаан лууг үнэн голоосоо үзэн ядаж, үйлдлээрээ Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгах ёстой ба ийм маягаар агуу улаан лууд ичгүүр авчирна. Агуу улаан луу жигшүүртэй гэдгийг та нар үнэхээр мэдэрч байна уу? Энэ нь хаанчлалын

Хааны дайсан гэдгийг та нар үнэхээр мэдэрч байна уу? Надад гайхалтай гэрчлэл хийж чадах тийм итгэл та нарт үнэхээр бий юу? Та нарт агуу улаан лууг ялах итгэл үнэхээр бий юу? Та нараас Миний шаарддаг зүйл энэ; та нар энэ алхамд хүрч чаддаг байх нь л Надад хэрэгтэй. Та нар үүнийг хийж чадах уу? Үүнд хүрэх итгэл та нарт байгаа юу? Хүн юу хийх чадвартай вэ? Харин ч Би үүнийг Өөрөө хийдэг биш гэж үү? Тулаан болох газарт Би биечлэн бууж очдог гэж Би яагаад хэлдэг вэ? Миний хүсдэг зүйл та нарын итгэл болохоос, үйл хэрэг чинь биш. Хүмүүс Миний үгийг шулуухан хүлээн авах чадваргүй, харин зүгээр л хажуугаас ажигладаг. Ингэснээр та нар зорилгодоо хүрсэн үү? Ийм маягаар та нар Намайг мэдэж авсан уу? Үнэнийг хэлэхэд, газар дээрх хүмүүсээс нэг нь ч Миний нүүр өөд эгцлэн харж чадахгүй, нэг нь ч Миний үгийн утгыг цэвэр, хольцгүй хүлээн авч чадахгүй. Иймээс Өөрийнхөө зорилгод хүрч, Өөрийн жинхэнэ дүрийг хүмүүсийн зүрх сэтгэлд байрлуулахын тулд Би урьд өмнө тохиолдож байгаагүй төслийг газар дэлхий дээр явуулсан. Ийм маягаар Би, үзэл нь хүмүүсийг эрхшээлдээ байлгадаг эринийг төгсгөнө.

Өнөөдөр Би агуу улаан лууны улс оронд бууж ирснээр үл барам, Өөрийн царайг бүхий л орчлон ертөнцийн зүг хандуулж, дээд тэнгэрийг тэр чигт нь донсолгож байна. Миний шүүлтэд өртөхгүй ганц ч гэсэн газар бий юу? Миний буулгасан гамшиг дор оршдоггүй ганц ч гэсэн газар бий юу? Би хаашаа ч явсан бүх төрлийн “гай гамшгийн үрийг” цацсан. Энэ нь Миний ажилладаг арга замуудын нэг, мөн хүнийг аврахын төлөө гэдэг нь эргэлзээгүй бөгөөд тэдэнд Миний хүртээдэг зүйл бол мөн л нэг төрлийн хайр юм. Бүр олон хүн Намайг мэдэж, Намайг харж чаддаг болж, ийм маягаар маш олон жилийн турш хараагүй боловч яг одоо бодитой байгаа Бурханыг хүндэлж эхлээсэй гэж Би хүсдэг. Би энэ дэлхийг ямар шалтгаанаар бүтээсэн бэ? Хүмүүсийг ялзарсан байдалтай болоход Би ямар учраас тэднийг бүрмөсөн устгаагүй вэ? Ямар учраас бүхий л хүн төрөлхтөн гай гамшиг дунд амьдардаг вэ? Махбод өмссөний минь зорилго юу вэ? Намайг ажлаа хэрэгжүүлж байхад амт нь гашуун төдийгүй, бас чихэрлэг болохыг хүмүүс мэддэг. Дэлхий дээрх бүх хүнээс Миний нигүүлсэл дотор амьдардаггүй хэн байна вэ? Би хүмүүст материаллаг ерөөл хүртээгээгүй бол энэ дэлхий дээр хэн ихийг эдэлж чадах байсан бэ? Та нарыг Өөрийн ардуудын байр сууринд аваачих нь ерөөл юм гэж үү? Та нар Миний ардууд биш, харин үйлчлэл үзүүлэгч байсан бол Миний ерөөл дотор оршихгүй байх байсан уу? Та нарын дотроос нэг нь ч Миний үгийн эх сурвалжийг ухан ойлгох чадваргүй. Хүмүүс Миний олгосон цолыг огтхон ч эрхэмлэн дээдэлдэггүй, харин “үйлчлэл үзүүлэгч” гэдэг цолоос үүдэн зүрх сэтгэлдээ гомдол агуулж явдаг нь их олон бөгөөд “Миний ард” гэдэг цолоос үүдэн зүрх сэтгэлдээ Намайг гэх хайраа өсгөдөг хүн олон байдаг. Хэн ч Намайг мэхлэхээр оролдох ёсгүй; Миний нүд бүхнийг хардаг! Та нарын дотроос хэн дуртайяа хүлээн авч, бүрэн дуулгавартай байдаг вэ? Хэрвээ хаанчлалын ёслолын буудлага тасхийгээгүй бол та нар эцэст нь хүртэл үнэхээр дуулгавартай дагаж чадах уу? Хүмүүс юу хийж, юу

бодох чадвартайг, мөн хэр хол явж чадахыг—энэ бүх зүйлийг Би аль эрт урьдчилан тодорхойлсон.

Хүмүүсийн асар олонх нь Миний нүүр царайны гэрэлд Миний шатаалтыг хүлээн авдаг. Хүмүүсийн асар олонх нь Миний зоригжуулалтаар өдөөгдөж, эрж хайн урагшлахаар үймэлддэг. Сатаны хүчнүүд Миний ардууд руу дайрах үед Би тэднийг няцаадаг; Сатаны явуулга тэдний амьдралыг сүйтгэх үед Би тэрнийг хэзээ ч эргэж ирэхгүйгээр бут ниргэдэг. Газар дээр төрөл бүрийн муу ёрын сүнс амрах газар хайн үүрд тэнүүчилж, идэж болох хүний цогцсыг эцэс төгсгөлгүй хайж байна. Миний ардууд аа! Та нар Миний халамж, хамгаалалт дотор үлдэх ёстой. Хэзээ ч бүү садар самуун бай! Хэзээ ч бүү болчимгүй авирла! Харин үнэнч байдлаа Миний гэрт өргөл болго, та нар диаволын арга мэхний эсрэг зөвхөн үнэнч байдлаар л сөрөг дайралт хийж чадна. Та нар ямар ч нөхцөл байдалд, өнгөрсөнтэйгээ адилаар авирлан, Миний өмнө нэгийг хийж, Миний ар хударгаар өөрийг хийх ёсгүй; тэгэх юм бол та нар аль хэдийн аврагдах аргагүй болжээ. Би иймэрхүү үг дэндүү ихийг айлдсан бус уу? Хүний хуучин уг чанар засаршгүй учраас л Би хүмүүст ахин дахин сануулах ёстой болсон. Бүү залх! Миний хэлж байгаа бүхэн та нарын хувь заяаг хамгаалахын төлөө байдаг! Бузар заваан газар л Сатанд яг хэрэгтэй зүйл юм; аврагдах найдваргүй байх тусам, мөн садар самуун байж, хориг хязгаарлалтад захирагдахаас татгалзах тусам бузар сүнснүүд та нарт нэвтрэх аливаа боломжийг төдий чинээ их ашиглана. Та нар энэ цэгт хүрсэн бол үнэнч байдал чинь ямар ч бодит зүйлгүй дэмий яриа болох ба бузар сүнснүүд шийдвэрийг чинь залгиж, дуулгаваргүй байдал юм уу сатанлаг явуулга болгон хувиргаад Миний ажлыг үймүүлэхэд ашиглана. Тэр үеэс Би та нарыг хэдийд ч цохиж болзошгүй. Энэ нөхцөл байдал хэчнээн ноцтой болохыг хэн ч ойлгодоггүй; хүмүүс бүгд сонссон зүйлээ чихнийхээ хажуугаар л өнгөрүүлдэг ба өчүүхэн төдий ч болгоомжтой байдаггүй. Урьд өмнө болсон зүйлсийг Би санадаггүй; Би дахин нэг удаа “мартсанаар” чамд өршөөнгүй хандана гэж чи үнэндээ хүлээсээр байна уу? Хүмүүс Намайг эсэргүүцсэн ч гэсэн Би тэрийг нь тэдний эсрэг хэрэглэхгүй, учир нь тэдний биеийн хэмжээ хэтэрхий жаахан, иймээс Би тэдэнд хэт өндөр шаардлага тавиагүй. Тэднээс Би садар самуун бус байж, хориг хязгаарлалтад захирагд гэж л шаарддаг. Энэ нэг болзлыг хангах нь та нарын чадвараас давсан зүйл биш биз дээ? Ихэнх хүн нүдээ хужирлахын тулд улам олон нууц илчлэхийг минь хүлээдэг. Гэсэн ч тэнгэрийн бүх нууцыг ойлголоо гэхэд чи тэр мэдлэгээрээ юу хийж чадах юм бэ? Энэ нь Намайг гэх хайрыг чинь ихэсгэх байсан уу? Энэ нь Намайг гэх хайрыг чинь төрүүлэх байсан уу? Би хүмүүсийг дутуу үнэлдэггүй, тэдний талаар хөнгөн хуумгай дүгнэлт ч гаргадаггүй. Эдгээр нь хүмүүсийн бодит нөхцөл байдал биш байсан бол Би хүмүүст ийм хаяг шошгыг хэзээ ч санамсаргүйгээр титэм адилаар өмсгөхгүй. Өнгөрснийг эргээд бод: Би та нарыг хэдэн удаа гүтгэсэн бэ? Би та нарыг хэчнээн удаа дутуу үнэлсэн бэ? Хэчнээн удаа Би бодит нөхцөл байдлыг чинь харгалзан үзэлгүйгээр та нарыг харсан бэ? Хэчнээн удаа Миний айлдвар та нарыг бүрэн үнэмшүүлж чадаагүй вэ?

Хэчнээн удаа Би та нарын сэтгэлийн утсыг хөндөлгүйгээр ярьсан бэ? Та нарын дундаас хэн чинь Миний үгийг айж, дагжилгүйгээр, өөрийг нь ёроолгүй нүх рүү цохин унагаана гэж гүнээ айлгүйгээр уншсан бэ? Миний үгэн доторх шалгалтыг туулдаггүй хэн байна вэ? Миний айлдварууд дотор эрх мэдэл оршдог, гэвч энэ нь хүмүүст санамсаргүй шүүлт оноохын төлөө байдаггүй; харин ч Би хүний бодит нөхцөл байдлыг анхааран үзэж, Миний үгэнд угаас байдаг утга учрыг тэдэнд байнга харуулдаг. Үнэндээ, Миний үгэнд буй бүхнийг чадагч хүчийг ухаарах чадвартай хүн байна уу? Миний үгийн шижир алтан бүтээгдэхүүнийг өөртөө хүлээн авч чадах хэн нэгэн байна уу? Би яг хэр олон үг хэлсэн бэ? Тэдгээрийг эрхэмлэсэн хүн ер нь байсан уу?

1992 оны 3 дугаар сарын 3

ХААНЧЛАЛЫН СҮЛД ДУУЛАЛ

Үй түмэн хүн Намайг уухайлдаг, үй олон хүн Намайг магтдаг; бүх ам нэгэн жинхэнэ Бурханыг дуудаж, бүх хүн Миний үйл хэргийг харахаар хараагаа бэлчээдэг. Хаанчлал хүний ертөнцөд бууж ирлээ, Миний үнэн бие баялаг агаад элбэг дэлбэг. Үүнд баясахгүй хэн байх билээ? Баяр хөөртэйгөөр бүжихгүй хэн байх билээ? Өө, Сион! Намайг тэмдэглэхийн тулд ялгуусан тугаа өргө! Ялалтын ялгуусан дуугаа дуулж, Миний ариун нэрийг түгээ! Газар дэлхийн зах хязгаар дахь бүх бүтээл ээ! Миний төлөө тахил болохоор өөрсдийгөө яаран цэвэрлэ! Тэнгэр дэх одод оо! Даруйхан байрандаа эргэн очиж огторгуйд Миний сүр хүчийг харуул! Намайг гэх дундаршгүй хайр хүндлэлээ шингээсэн газар дээрх хүмүүсийн дууг Би чих тавин сонсож байна! Бүх бүтээл эргэн амилах энэ өдөр, Би хүний ертөнцөд буун ирсэн. Энэ мөчид, яг энэ үед бүх цэцэг цоморлогоо дэлгэж, бүх шувуу нэгэн өнгөөр жиргэж, бүх зүйл баяр хөөрөөр цалгидаг! Хаанчлалын ёслолын буудлагын дуунаар Сатаны хаанчлал нуран унаж, хаанчлалын сүлд дууллын нүргээнд дахин хэзээ ч өндийхгүйгээр устан үгүй болдог!

Газар дээр хэн өндийн босож, эсэргүүцэж зүрхлэх билээ? Газар луу буухдаа Би шатаалт, уур хилэн, бүх гай гамшиг авчирдаг. Газар дээрх хаанчлалууд одоо Миний хаанчлал болсон! Тэнгэрт үүлс хөлбөрөн нүүгэлтдэг; тэнгэрийн дор гол нуурууд долгилж, сэтгэл уярам аялгууг баясалтайгаар урсгадаг. Ичсэн амьтад үүрнээсээ гарч, бүх хүнийг Би зүүд нойрноос нь сэрээдэг. Түмэн олон ардын хүсэн хүлээсэн өдөр эцэстээ ирлээ! Тэд хамгийн сайхан дууг Надад өргөн барьдаг!

Ийм сайхан мөчид, энэхүү баярт цаг үед,

дээд тэнгэр, доод газарт хаа сайгүй магтаал ундардаг. Хэн үүнд баярлан хөөрөхгүй байх билээ?

Хэний зүрх сэтгэл уужрахгүй байх билээ? Хэн энэ дүр зурагт нулимс унагахгүй байх билээ?
Тэнгэр урьдын тэнгэр байхаа больж, одоо хаанчлалын тэнгэр болсон.
Газар өмнөх шигээ биш болж, одоо ариун газар болсон.
Аадар бороо өнгөрсний дараа бузар хуучин ертөнц бүрэн шинэчлэгдсэн.
Уулс өөрчлөгдөж байна … ус өөрчлөгдөж байна…
хүмүүс ч бас өөрчлөгдөж байна … бүх зүйл өөрчлөгдөж байна…
Ай, аниргүй уулс аа! Босоод Миний төлөө бүж!
Ай, тогтоол ус аа! Цааш чөлөөтэй урс!
Зүүдэлж буй хүмүүс ээ! Сэрээд эрж хай!
Би ирсэн … Би хаанчилсан…
Бүх хүн Миний царайг нүдээрээ харж, дуу хоолойг минь чихээрээ сонсож, хаанчлалын амьдралаар өөрсдөө амьдарна…
Хэчнээн жаргалтай … хэчнээн сайхан гээч…
Мартагдашгүй … мартахын аргагүй…

Миний уур хилэнгийн галд агуу улаан луу тэмцэлдэнэ;
Миний сүр жавхлант шүүлтээр диаволууд жинхэнэ төрхөө харуулна;
Миний хатуу үгэнд хүмүүс бүгд гүнээ ичиж, нүүр хийх газаргүй болдог.
Өөрийг минь дооглож, тохуурхаж байснаа тэд эргэн санадаг.
Онгирч бардаагүй цаг үе тэдэнд огт үгүй, Намайг эсэргүүцэж байгаагүй цаг үе гэж хэзээ ч үгүй.
Өнөөдөр уйлаагүй хэн байна? Гэмшиж харуусаагүй хэн байна?
Орчлон тэр аяараа уйлаан майлаанд автдаг…
баяр баяслын дуугаар бялхдаг … инээд хөөрөөр цалгидаг…
Зүйрлэшгүй их баяр хөөр … зүйрлэх аргагүй баяр хөөр…

Зөөлөн бороо шивэрч … их цас малгайлан бударна…
Хүмүүсийн сэтгэлд баяр хөөр, уйтгар гуниг сүлэлдэнэ … зарим нь инээнэ…
зарим нь уйлна … бас зарим нь уухайлна…
Үүлэрхэг, хуртай хавар уу, цэцэгс дэлгэрсэн зун уу,
арвин ургацтай намар уу, жавартай хүйтэн өвөл үү гэдгийг
хүн бүр мартчихсан мэт, хэн ч мэдэхгүй…
Тэнгэрт үүлс хөвж, газарт тэнгис цалгилна.
Хөвгүүд гараа даллаж … хүмүүс цогин бүжнэ…
Тэнгэрэлчүүд ажиллаж … тэнгэрэлчүүд хонь хариулж байна…
Газар дээрх хүмүүс яаравчилж, газар дээрх бүх зүйл олширч байна.

11-Р БҮЛЭГ

Хүн төрөлхтний хүн болгон Миний Сүнсний шинжилтийг хүлээн авч, өөрсдийн үг, үйлдэл бүрийг сайтар шинжлэх ёстой, түүнчлэн Миний гайхалтай үйл хэргийг харах ёстой. Хаанчлал газар дээр буун ирэх үед та нарт ямар санагддаг вэ? Миний хөвгүүд болон ардууд Миний сэнтий рүү цутгах үед агуу цагаан сэнтийн өмнөх шүүлтийг Би албан ёсоор эхлүүлнэ. Өөрөөр хэлбэл, газар дээрх ажлаа биечлэн эхлэх үедээ, мөн шүүлтийн эрин үе төгсгөлдөө ойртох үед Би Өөрийн үгийг бүх орчлон ертөнц рүү чиглүүлж, Өөрийн Сүнсний дуу хоолойг бүх орчлон ертөнцөд гаргаж эхэлдэг. Өөрийн үгээр дамжуулан Би тэнгэр газар дахь бүх зүйлийг болон бүх хүнийг цэвэрлэн угаана, ингэснээр газар дэлхий бохир заваан, садар самуун байхаа болиод, харин ариун хаанчлал болно. Би бүх зүйлийг шинэчилнэ, ингэснээр тэд Миний хэрэгцээг хангах ба цаашид газар дэлхийн амьсгалыг агуулахгүй, газрын амтаар цаашид сэвтэхгүй. Хүн газар дээр Миний үгийн эх сурвалж, зорилгыг бэдрэн хайж, Миний үйл хэргийг ажигласан хэдий ч Миний үгийн эх сурвалжийг хэн ч хэзээ ч үнэхээр мэдээгүй, Миний үйл хэргийн гайхалтай байдлыг хэн ч хэзээ ч үнэхээр хараагүй. Өнөөдөр, Өөрийн үгийг хэлэхээр хүмүүсийн дунд биечлэн ирэхэд минь л хүмүүс Миний талаар бага зэргийн мэдлэгтэй болж, өөрсдийнх нь бодол дотор “Миний” эзэлсэн орон зайг арилгаад, өөрсдийнхөө ухамсарт бодитой Бурханы орон зайг бий болгодог. Хүнд үзэл байдаг ба сониуч зангаар дүүрэн байдаг; Бурханыг харахыг хүсдэггүй хэн байх билээ? Бурхантай уулзахыг хүсдэггүй хэн байх билээ? Гэсэн ч хүний зүрх сэтгэлд тодорхой орон зайг эзэлдэг цорын ганц зүйл нь тодорхой бус, хийсвэр санагддаг Бурхан юм. Хэрвээ Би тэдэнд ний нуугүй хэлээгүй бол хэн үүнийг ухаарах юм бэ? Намайг үнэхээр оршин тогтнодог гэдэгт хэн өчүүхэн ч эргэлзэлгүйгээр үнэхээр баттай итгэх юм бэ? Хүний зүрх сэтгэл дэх “Би” болон бодит байдлын “Би”-гийн хооронд үлэмж их ялгаа байдаг ба хэн ч тэднийг хооронд нь харьцуулж чадахгүй. Хэрвээ Би махбод болоогүй бол хүн хэзээ ч Намайг мэдэхгүй байх байсан бөгөөд Намайг мэдэж авсан ч гэсэн тийм мэдлэг нь мөн л үзэл байх бус уу? Би хүмүүсийн тасралтгүй урсгал дунд өдөр бүр алхаж, өдөр бүр хүн болгоны дотор ажилладаг. Хүн үнэхээр Намайг харах үедээ Миний үгээс Намайг мэдэж, Миний ярьж буй арга барилыг, түүнчлэн Миний санаа зорилгыг ухаарч чадна.

Хаанчлал албан ёсоор газар дээр ирэх үед бүх зүйлийн дотроос юу чимээгүй байдаггүй вэ? Бүх хүний дундаас хэн айдаггүй вэ? Би орчлон ертөнц даяар хаа сайгүй алхаж, бүх зүйлийг биечлэн зохицуулдаг. Энэ үед, Миний үйл хэрэг гайхалтай гэдгийг хэн мэдэхгүй байх вэ? Миний гар бүх зүйлийг атгадаг ч Би бас бүх зүйлийн дээр байдаг. Өнөөдөр, Би бие махбодтой болж, хүмүүсийн дунд биечлэн байгаа нь Миний даруу, нууцлаг байдлын жинхэнэ утга учир биш гэж үү? Гаднаа олон хүн Намайг сайн хэмээн биширч, сайхан хэмээн магтдаг ч хэн Намайг үнэхээр мэдэх билээ? Өнөөдөр, Намайг мэд гэж Би яагаад та нараас шаарддаг вэ? Миний зорилго бол агуу улаан лууг шившиглэх явдал биш гэж үү? Би Өөрийгөө

магтуулахын тулд хүнийг хүчлэхийг хүсдэггүй, харин Өөрийгөө хүнд мэдүүлэхийг хүсдэг, ингэснээр тэр Намайг хайрлах болж, улмаар Намайг магтана. Тийм магтаал нь нэрэндээ таарах бөгөөд энэ нь дэмий хоосон яриа биш; иймэрхүү магтаал л Миний сэнтийд хүрч, тэнгэр лүү хөөрч чадна. Хүн Сатанд уруу татагдаж, завхарсан учраас, мөн үзэл, сэтгэлгээнд автсан учраас бүх хүн төрөлхтнийг биечлэн байлдан дагуулж, хүний бүх үзлийг илчилж, хүний сэтгэлгээг тасар татахын тулд Би махбод болсон. Үүний үр дүнд, хүн Миний өмнө өөрийгөө гайхуулахаа больж, өөрийн үзлийг ашиглан Надад үйлчлэхээ болиод, улмаар хүний үзэл дэх “Би” бүрмөсөн сарнидаг. Хаанчлал ирэх үед Би юун түрүүнд ажлын энэ үе шатыг эхэлж, Өөрийн ардуудын дунд үүнийг хийдэг. Агуу улаан лууны улс оронд төрсөн Миний ардуудын хувиар та нарын дотор агуу улаан лууны хор жаахан ч, эсвэл хэсэгхэн ч биш, гарцаагүй байгаа. Тиймээс, Миний ажлын энэ үе шат голчлон та нар дээр төвлөрдөг, энэ нь Хятадад бие махбодтой болсны минь ач холбогдлын нэг тал юм. Дийлэнх хүмүүс Миний хэлж байгаа үгийн нэг хэсгийг ч ухаарч чаддаггүй ба ухаарах үедээ тэдний ойлголт нь бүдэг бадаг, будилсан байдаг. Энэ нь Миний ярьдаг арга барилын эргэлтийн цэг юм. Хэрвээ бүх хүн Миний үгийг уншиж, утга учрыг нь ойлгож чаддаг байсан бол хүмүүсийн дундаас хэн Үхэгсдийн орон руу хаягдалгүй, аврагдаж чадах байсан бэ? Хүн Намайг мэдэж, Намайг дуулгавартай дагах үе нь Миний амрах үе байх болно, мөн энэ нь хүн Миний үгийн утгыг ухаарч чаддаг болсон тэр цаг үе байх болно. Өнөөдөр та нарын биеийн хэмжээ хэтэрхий жаахан, эгээ л өрөвдмөөр жаахан, бүр өргөгдөхөд ч зохисгүй—Миний талаарх та нарын мэдлэгийг бол хэлэхийн ч хэрэггүй.

Миний хөвгүүд болон ардуудыг хариулахын тулд тэнгэрэлчүүд илгээгдэж эхэлсэн гэж Би хэлсэн хэдий ч Миний үгийн утгыг хэн ч ойлгож чаддаггүй. Намайг хүмүүсийн дунд биечлэн ирэхэд тэнгэрэлчүүд хариулах ажлаа нэгэн зэрэг эхэлдэг ба тэнгэрэлчүүд хариулах үеэр хөвгүүд болон ардууд бүгд шалгалт, хариулгыг хүлээн аваад зогсохгүй, төрөл бүрийн үзэгдэл тохиолдохыг өөрсдийн нүдээр харж чаддаг. Би шууд бурханлаг чанараар ажилладаг учраас бүх зүйл шинэ эхлэл рүү ордог, мөн энэхүү бурханлаг чанар шууд ажилладаг учраас хүн чанараар өчүүхэн төдий ч хязгаарлагддаггүй бөгөөд ер бусын нөхцөл байдал дор чөлөөтэй ажиллаж байгаа мэт хүнд санагддаг. Гэсэн ч, Миний хувьд энэ нь тэр чигтээ хэвийн (бурханлаг чанартай хэзээ ч тулгарч байгаагүй учраас хүн үүнийг ер бусын гэж үздэг); үүнд хүний нэг ч үзэл байдаггүй, хүний санаа бодол холилддоггүй. Хүмүүс бүгд зөв замд орох үедээ л үүнийг харна; одоо үе бол эхлэл учраас хүний оролтын тухайд гэвэл түүнд маш олон дутагдал байдаг ба бүтэлгүйтэл, тодорхой бус байдлаас зайлсхийж бараг чадахгүй. Өнөөдөр та нарыг өдий хүртэл удирдан хөтөлсөн учраас Би тохирсон зохицуулалтыг хийсэн бөгөөд Надад өөрийн гэсэн зорилго бий. Хэрвээ Би үүнийгээ та нарт өнөөдөр хэлсэн бол та нар үнэхээр тэдгээрийг мэдэж чадна гэж үү? Би хүний оюун ухаан дахь бодол, хүний зүрх сэтгэлийн хүслийг нэлээд сайн мэддэг: Өөрсдөдөө гарах гарц хэзээ ч хайж

байгаагүй хэн байна вэ? Өөрсдийн хэтийн ирээдүйг хэзээ ч бодож байгаагүй хэн байна вэ? Хүн баялаг, гялалзсан оюуны чадавхтай хэдий ч эрин үеүдийн дараа өнөө үе ийм болно гэдгийг хэн урьдчилан таамаглаж чадсан билээ? Энэ нь үнэхээр бодит хичээл чармайлтын чинь үр дүн гэж үү? Цуцашгүй зүтгэлийн чинь төлбөр гэж үү? Оюун ухаандаа ургуулан бодсон үзэсгэлэнт дүр зураг чинь гэж үү? Хэрвээ Би бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлээгүй бол хэн өөрсдийгөө Миний зохицуулалтаас салгаж, өөр гарц олж чадах юм бэ? Хүний төсөөлөл, хүсэл нь түүнийг өдий хүргэсэн юм гэж үү? Олон хүн өөрсдийн хүслийг биелүүлэлгүйгээр бүх амьдралаа өнгөрүүлдэг. Энэ нь үнэхээр тэдний сэтгэхүй дэх алдаанаас болсон гэж үү? Олон хүний амьдрал гэнэтийн аз жаргал, сэтгэл ханамжаар дүүрэн байдаг. Энэ нь, үнэхээр тэд хэтэрхий багыг хүлээдгээс болдог гэж үү? Бүх хүн төрөлхтнөөс хэн нь Төгс Хүчитийн нүдэнд анзаарагддаггүй вэ? Хэн Төгс Хүчитийн урьдаас тогтоосон тавилангаар амьдардаггүй вэ? Хүний амьдрал, үхэл өөрсдийнх нь сонголтоор тохиолддог уу? Хүн хувь заяагаа хянадаг уу? Олон хүн үхлийг урин дууддаг ч энэ нь тэднээс хол байдаг; олон хүн амьдралдаа хүчтэй хүн байхыг хүсэж, үхлээс айдаг ч нэг л мэдэхэд үхэх өдөр нь ойртож, тэднийг үхлийн ангал руу унагадаг; олон хүн тэнгэр лүү хараад, гүнзгий санаа алддаг; олон хүн асар их уйлж, цурхиран гасалдаг; олон хүн шалгалт дунд унадаг; мөн олон хүн уруу таталтын олзлогдогсод болдог. Хэдийгээр хүнд Өөрийгөө тодорхой харуулахын тулд Би биечлэн гарч ирээгүй ч олон хүн Миний царайг харахаас айж, өөрсдийг нь цохих вий, мөн сөнөөх вий гэж үхтэлээ айдаг. Хүн Намайг үнэхээр мэддэг үү, эсвэл мэддэггүй юу? Хэн ч итгэлтэй хэлж чадахгүй. Тийм биз дээ? Та нар Надаас болон Миний гэсгээлтээс хоёулангаас нь айдаг атлаа өндийн босож, Намайг илт эсэргүүцэж, Намайг шүүдэг. Тийм биш гэж үү? Хүн хэзээ ч Миний царайг харж, Миний дуу хоолойг сонсож байгаагүй учраас Намайг огт мэдээгүй. Тиймээс, хэдийгээр Би хүний зүрх сэтгэл дотор байдаг ч хэний зүрх сэтгэл дотор Би бүрхэг, бүдэг бадаг биш байдаг вэ? Хэний зүрх сэтгэл дотор Би тов тодорхой байдаг вэ? Миний ардууд Намайг бүдэг бадаг, тодорхой бусаар харахыг Би хүсдэггүй тул энэ агуу ажлыг эхлүүлсэн юм.

Би хүмүүсийн дунд чимээгүй ирж, дараа нь хөвөн оддог. Хэн ер нь Намайг харсан юм бэ? Нар шатаж буй дөлийнхөө улмаас Намайг харж чадна гэж үү? Сар гялалзсан тунгалаг байдлынхаа улмаас Намайг харж чадна гэж үү? Одны ордууд тэнгэр дэх байрлалынхаа улмаас Намайг харж чадах уу? Намайг ирэх үед хүн мэддэггүй ба бүх зүйл мэдэхгүй хэвээр байдаг, Намайг явах үед ч хүн мөн л мэддэггүй. Хэн Надад гэрчлэл хийж чадах юм бэ? Газар дээрх хүмүүсийн магтаал уу? Зэрлэг талд цэцэглэж байгаа сараана цэцэг үү? Тэнгэрт нисэж буй шувууд уу? Ууланд архирч буй арслангууд уу? Хэн ч Намайг бүрэн гэрчилж чадахгүй! Миний хийх ажлыг хэн ч хийж чадахгүй! Тэд энэ ажлыг хийсэн ч гэсэн энэ нь ямар үр нөлөөтэй байх юм бэ? Би өдөр бүр олон хүний үйлдэл болгоныг ажиглаж, өдөр бүр олон хүний зүрх сэтгэл, оюун ухааныг шинжилдэг; хэн ч хэзээ ч Миний шүүлтээс зугтаж байгаагүй, хэн ч хэзээ ч Миний шүүлтийн бодит байдлаас өөрсдийгөө

салгаагүй. Би тэнгэрийн дээр зогсож, алс холыг хардаг: Хэмжээлшгүй олон хүн Надад цохиулсан, гэсэн ч мөн тоо томшгүй олон хүн Миний өршөөл, хайр энэрэл дунд амьдардаг. Та нар ч гэсэн тийм нөхцөл байдалд амьдардаггүй гэж үү?

1992 оны 3 дугаар сарын 5

12-Р БҮЛЭГ

Аянга зүүн зүгээс цахих үе нь бас Би үгээ айлдаж эхлэх яг тэр мөч бөгөөд—аянга цахих үед бүхий л орчлон ертөнц гэрэлтэж, бүх од хувирдаг. Бүх хүн төрөлхтөн ангилагдсан мэт байдаг. Зүүн зүгийн гэрлийн энэхүү цацрагийн туяан дор бүх хүн төрөлхтний анхдагч төрх илчлэгдэж, нүд нь гялбаж, яахаа мэддэггүй бөгөөд үзэшгүй муухай төрхөө яаж нуухаа бүр ч мэддэггүй. Тэд бас Миний гэрлээс зугтан уулын агуй руу дүрвэж байгаа амьтадтай адил байдаг—гэхдээ тэдний дундаас хэн нь ч Миний гэрэл дотроос арчигдан арилж чадахгүй. Бүх хүн гайхаж, бүгд хүлээсээр, бүгд харсаар байгаа; Миний гэрэл ирснээр бүгд өөрсдийн төрсөн өдөрт баярлахын сацуу өөрсдийн төрсөн өдрийг хараадаг. Зөрчилдөөнтэй сэтгэл хөдлөлийг тодорхой илэрхийлэх боломжгүй; өөрийгөө зэмлэсэн нулимс нь гол горхи үүсгэн, хүчтэй ширүүн урсгалд урсаж, нүд ирмэх төдийд ул мөргүй арилна. Миний өдөр дахин нэг удаа хүн төрөлхтөнд ойртож ирэн, хүн төрөлхтнийг дахин нэгэнтээ сэрээж, хүн төрөлхтөнд шинээр эхлэх цэгийг өглөө. Миний зүрх цохилж, Миний зүрхний цохилтыг дагаад уулс баяртайгаар дэвхэрч, ус баярлан бүжиж, давлагаа хадан цохио мөргөнө. Миний зүрх сэтгэлд юу байгааг илэрхийлэхэд хэцүү. Би бүх бохир зүйлийг Өөрийн харцны дор үнс нурам болтол шатаахыг хүсдэг; бүх дуулгаваргүй хөвгүүдийг дахин хэзээ ч оршин тогтнуулалгүй, нүднийхээ өмнөөс арилгахыг хүсдэг. Би агуу улаан лууны аж төрдөг газарт шинэ эхлэлийг бий болгоод зогсоогүй, мөн орчлон ертөнц дээр шинэ ажил эхлүүлсэн. Удалгүй дэлхийн хаанчлалууд Миний хаанчлал болно; удалгүй Миний хаанчлалаас болж, мөн Би аль хэдийн ялалтад хүрч, ялгууснаар эргэн ирснээс болж газар дээрх хаанчлалууд оршин тогтнохоо үүрд болино. Агуу улаан луу Миний төлөвлөгөөг тасалдуулахын тулд боломжтой бүр аргыг барж, газар дээрх Миний ажлыг үгүй болгохоор найдсан, гэхдээ түүний зальжин арга мэхнээс болж Миний зориг мохож болох уу? Би түүний заналхийллээс сүрдээд итгэл найдвараа алдаж болох уу? Миний гарт байдаггүй ганц ч зүйл тэнгэрт ч, газарт ч хэзээ ч байгаагүй; товойлгогч болж Надад үйлчилдэг энэ хэрэгсэл буюу агуу улаан лууны хувьд бүр ч тийм байдаг бус уу? Тэр ч гэсэн Миний гараар жолоодуулдаг зүйл биш гэж үү?

Намайг хүний ертөнцөд бие махбодтой болсон үед хүн төрөлхтөн Миний удирдамж дор өөрийн мэдэлгүй өдий хүрч, өөрийн мэдэлгүй Намайг мэдэж авсан. Гэвч өмнө нь буй замаар яг хэрхэн алхах талаар хэн ч таамагладаггүй, хэн ч

мэддэггүй—тэрхүү зам өөрсдийг нь хааш аваачихыг мэдэх хүн бүр ч байдаггүй. Зөвхөн Төгс Хүчит харж хандвал л хүн замын төгсгөл хүртэл явж чадна; зүүн зүг дэх аянгаар замчлуулснаар л хүн Миний хаанчлалын хаалгаар алхан орж чадна. Хүмүүсийн дунд Миний царайг харсан хүн, зүүн зүгийн аянгыг харсан хүн хэзээ ч байгаагүй; тэгвэл Миний сэнтийгээс гарч буй айлдварыг сонссон хүн хэчнээн цөөхөн байх билээ? Үнэндээ, эрт дээр үеэс хойш нэг ч хүн Миний үнэн биетэй шууд харилцаагүй; өнөөдөр л дэлхий дээр ирсэн үед минь хүмүүс Намайг харах боломжтой болсон. Гэхдээ одоо ч гэсэн хүмүүс Намайг мэдэхгүй хэвээр байна, тэд юу гэж байгааг минь ойлголгүйгээр зүгээр л Миний царайг харж, Миний дуу хоолойг сонсдог. Бүх хүн ийм байдаг. Миний ардуудын нэг болохоор та нар Миний царайг харахдаа гүн гүнзгий бахархлыг мэдэрдэг бус уу? Та нар Намайг мэддэггүй учраас адгийн ичгүүрийг мэдэрдэг бус уу? Би хүмүүсийн дунд алхаж, хүмүүсийн дунд амьдардаг, учир нь Би махбод болж, хүний ертөнцөд ирсэн билээ. Миний зорилго бол хүмүүст Өөрийн махан биеийг харуулах төдийхөн биш; үүнээс ч чухал нь Өөрийгөө мэдүүлэх явдал юм. Түүнчлэн, Би Өөрийн махбод болсон биеэр дамжуулан хүнийг нүглийнх нь төлөө яллана; Өөрийн махбод болсон биеэр дамжуулан Би агуу улаан лууг ялж, ичээг нь бүрмөсөн устгана.

Хэдийгээр газар дэлхийд суурьшсан хүмүүс тэнгэрийн од шиг тоо томшгүй олон боловч Би тэднийг бүгдийг нь алган дээрээ тавьсан мэт тодорхой мэддэг. Мөн Намайг “хайрладаг” хүмүүс далайн элс мэт тоолж баршгүй хэдий ч тун цөөхөн хүнийг л Би сонгодог: Намайг “хайрладаг” хүмүүсээс гадна хурц гэрлийг эрэлхийлдэг хүмүүс л сонгогддог. Би хүнийг хэт өндрөөр үнэлдэггүй, бас дутуу ч үнэлдэггүй; харин угийн шинж чанарт нь тааруулан хүнд шаардлага тавьдаг тул хүмүүсийг сонгох зорилгоо биелүүлэхийн тулд Би Намайг чин сэтгэлээсээ эрж хайдаг хүнийг л шаарддаг. Ууланд тоймгүй олон зэрлэг араатан байдаг ч Миний өмнө бүгд хонь шиг номхон байдаг; далайн давлагаан дор ойлгошгүй олон гайхамшиг оршдог боловч Миний өмнө өөрсдийгөө газрын гадарга дээрх бүх зүйлтэй адил тодорхой харуулдаг; дээд тэнгэрүүдэд хүний хэзээ ч хүрч чадахгүй ертөнц байдаг, харин тэдгээр хүршгүй ертөнцөд Би чөлөөтэй алхалдаг. Хүн Намайг гэрэлд хэзээ ч таниагүй, харин Намайг харанхуйн ертөнцөд л харсан. Та нар ч гэсэн өнөөдөр яг адилхан нөхцөл байдалд байгаа биш гэж үү? Агуу улаан лууны галзуу хилэн оргилдоо хүрэх цагт Би Өөрийн ажлыг албан ёсоор махбодоор эхлүүлсэн. Агуу улаан луу жинхэнэ дүр төрхөө анх удаа илчилсэн үед Би Өөрийн нэрийг гэрчилсэн. Намайг хүн төрөлхтний замаар алхах үед нэг ч амьтан, нэг ч хүн цочиж сэрээгүй тул бие махбодтой болоод хүний ертөнцөд ирэхэд минь хэн ч мэдээгүй. Гэхдээ Өөрийн махбод болсон биеэр ажлаа хийж эхэлсний дараа Миний нижигнэсэн дуунаар хүмүүс зүүднээсээ цочин сэрж, энэ мөчөөс эхлэн Миний удирдамж дор амьдарч эхэлсэн. Өөрийн ардуудын дунд Би шинэ ажлыг дахин нэгэнтээ эхлүүлсэн. Газар дээрх Миний ажил дуусаагүй гэж хэлсэн нь Миний ярьсан Миний ардууд бол зүрх сэтгэлдээ Миний шаарддаг хүмүүс биш гэдгийг хангалттай харуулдаг, гэсэн ч Би тэдний дундаас заримыг нь мөн л

сонгодог. Би Өөрийн ардуудад бие махбодтой болсон Бурханыг мэдүүлээд зогсохгүй, бас тэднийг цэвэрлэдэг нь үүнээс илэрхий юм. Миний захиргааны зарлиг хатуу чандаас болж хүмүүсийн дийлэнх олонх нь Надад таягдуулан хаягдах аюулд байсаар байгаа. Та нар өөрсөдтэйгөө харьцахын тулд хамаг хичээл чармайлтаа гаргаж, өөрсдийн биеийг захирахгүй бол—ингэхгүй л бол яг л Паул шууд Миний гараас гэсгээлт хүртээд, үүнээс зугтах аргагүй байсантай адилаар Миний жигшин голдог бай болж, там руу хаягдах нь гарцаагүй. Та нар Миний үгээс ямар нэг зүйлийг олж мэдэж авсан уу? Би бол бүхэлдээ ариун, өө сэвгүй Бурхан Өөрөө учраас урьдын адилаар чуулганыг цэвэрлэж, Өөрт хэрэгтэй хүмүүсийг үргэлжлүүлэн ариусгах нь Миний санаа зорилго юм. Би Өөрийн сүмийг солонгын өнгөөр солонгоруулах төдийгүй дотор талыг нь гадна талтайгаа зохицохуйц өө сэвгүй цэвэрхэн болгоно. Миний өмнө та нар дор бүрнээ урьд нь юу хийснээ тунгаан бодож, өнөөдөр Миний зүрх сэтгэлийг төгс хангалуун болгохоор сэтгэл шулуудаж чадах эсэхээ шийдэх хэрэгтэй.

Хүн ердөө махбодод байгаа Намайг мэддэггүй ч юм биш; үүнээс гадна тэр махан биед оршдог өөрийгөө ч ойлгож чадаагүй. Маш олон жилийн турш хүмүүс Намайг мэхэлж, Надад гаднаас ирсэн зочин мэт хандсаар ирсэн. Маш олон удаа тэд Намайг “гэрийнхээ хаалганы” гадна үлдээн хаалгаа хаасан; маш олон удаа Миний өмнө зогсоод Надад ямар ч анхаарал хандуулаагүй; маш олон удаа тэд бусад хүмүүсийн дунд Надаас татгалзсан; маш олон удаа тэд Намайг диаволын өмнө үгүйсгэсэн; маш олон удаа тэд хэрүүлч амаараа Над руу дайрч давшилсан. Гэсэн ч Би хүний сул талуудыг санадаггүй, дуулгаваргүй байдлаас нь үүдэн шүдийг шүдээр төлөхийг шаарддаггүй. Би гагцхүү түүний эдгэшгүй өвчнийг эдгээж, улмаар эрүүл саруул болгохын тулд өвчинд нь эм хэрэглэсэн бөгөөд ингэвэл тэр Намайг мэдэж авч магадгүй юм. Миний хийсэн бүхэн хүний оршин тогтнолын төлөө, хүний амьдралд боломж олгохын төлөө байгаагүй гэж үү? Олон удаа Би хүний ертөнцөд ирсэн боловч Өөрийн үнэн биеэр энэ дэлхийд ирснээс болж хүмүүс Намайг огт тоогоогүй; харин ч хүссэнээрээ авирлаж, өөртөө л гарах гарц хайсан. Тэнгэрийн доорх зам нэг бүр Миний гараас бий болдог гэдгийг тэд ер мэддэггүй! Тэнгэрийн доорх юм болгон Миний тушаалд захирагддаг гэдгийг тэд ер гадарладаггүй! Та нараас хэн зүрх сэтгэлдээ гомдол дургүйцэл өвөрлөж зүрхэлдэг вэ? Та нараас хэн яаран дүгнэлт гаргаж зүрхэлдэг вэ? Би зүгээр л хүмүүсийн дунд Өөрийнхөө ажлыг чимээгүйхэн хийсээр ирсэн. Хэрвээ бие махбодтой байх хугацаандаа Би хүний сул талыг өрөвдөөгүй бол гагцхүү бие махбодтой болсноос минь болж бүх хүн ухаанаа алдтал айчхаад, түүнийхээ уршгаар Үхэгсдийн оронд уначихсан байх байлаа. Би Өөрийгөө даруухан байлгаж, Өөрийгөө нуусан учраас л хүмүүс гай гамшгаас зайлж, Миний гэсгээлтээс ангижирсан ба ийм маягаар өнөөдрийг хүрсэн. Өнөөдрийг хүрэх нь хэчнээн хэцүү байсныг бодолцон үзээд та нар хүрэлцэн ирэх маргаашийг бүр ч илүү ихээр нандигнах ёстой бус уу?

1992 оны 3 дугаар сарын 8

13-Р БҮЛЭГ

Миний үг, айлдвар дотор өдий төдий санаа зорилго минь нуугдаж байдаг ч хүмүүс эдгээрийн талаар юу ч мэддэггүй, бас ойлгодоггүй; тэд Миний үгийг гаднаас нь хүлээн авч, гаднаас нь дагасаар байдаг ба Миний үгэн дотроос Миний зүрх сэтгэлийг ойлгох юм уу Миний хүслийг зөнгөөрөө мэдэрч чадахгүй. Би Өөрийнхөө үгийг ойлгомжтой хэлсэн ч хэн тэдгээрийг ойлгодог билээ? Би Сионоос хүн төрөлхтөн рүү ирсэн. Би Өөрийгөө хэвийн хүн чанар болон хүний арьсаар хувцасласан учраас хүмүүс ердөө гадна талаас Миний дүр төрхийг мэдэж авдаг боловч Миний дотор оршдог амийг мэддэггүй, Сүнсний Бурханыг ч таньдаггүй, зөвхөн махан биетэй хүнийг л мэддэг. Бодитой Бурхан Өөрөө, Түүнийг мэдэх гэсэн та нарын оролдлогыг хүртэх үнэ цэнгүй юм гэж үү? Бодитой Бурхан Өөрөө, Түүнийг “задлан шинжлэх” хичээл зүтгэлийг чинь хүртэх үнэ цэнгүй юм гэж үү? Би бүх хүн төрөлхтний ялзралыг жигшдэг, гэхдээ сул дорой байдлыг нь өрөвддөг. Бас Би бүх хүн төрөлхтний хуучин уг чанартай харьцаж байгаа. Хятад дахь Миний ардуудын нэг болохын хувьд та нар ч бас хүн төрөлхтний нэг хэсэг биш гэж үү? Миний бүх ард, Миний бүх хөвгүүдийн дундаас, өөрөөр хэлбэл, бүх хүн төрөлхтнөөс Миний сонгож авсан хүмүүсийн дундаас та нар хамгийн доод бүлэгт харьяалагддаг. Энэ шалтгааны улмаас Би та нарт хамгийн их энерги, хамгийн их хүчин чармайлт гаргасан. Та нар өнөөдрийн эдэлж буй ерөөгдсөн амьдралаа бас л нандигнадаггүй гэж үү? Та нар Миний эсрэг тэрсэлж, өөрийн санаагаар үйлдэхээр зүрх сэтгэлээ хатуужуулсаар байна уу? Миний тасралтгүй өрөвдөх сэтгэл, хайр байгаагүй сэн бол бүх хүн аль эрт Сатанд олзлогдож, түүний аман дахь “сайхан зууш” болох байлаа. Өнөөдөр бүх хүний дунд Миний төлөө өөрсдийгөө чин сэтгэлээсээ зарлагадаж, Намайг чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүс хуруу дарам цөөхөн байна. Өнөөдөр “Миний ардууд” гэсэн цол та нарын хувийн өмч болж болох уу? Мөс чанар чинь зүгээр л мөс шиг хүйтэн болчихсон юм уу? Чи үнэхээр Миний шаарддаг ард болох үнэ цэнтэй юу? Өнгөрснөө эргэн дурсаж өнөөдрийг дахин харвал та нарын хэн чинь Миний зүрх сэтгэлийг хангалуун болгосон бэ? Та нарын хэн чинь Миний санаа зорилгын төлөө үнэн голоосоо сэтгэл гаргасан бэ? Хэрвээ Би сануулаагүй бол та нар одоо ч гэсэн сэрээгүй, харин хөлдсөн мэт, мөн ичээндээ орсон мэт хэвээр үлдэх байлаа.

Булингартсан давлагаан дунд хүн Миний уур хилэнг хардаг; нүргэлэх үй олон хар үүлсийн дунд хүмүүс ухаан алдталаа айж, хаашаа зугтахаа мэдэхгүй яг л аянга цахилгаант бороо өөрсдийг нь угааж арилгахаас айж байгаа мэт байдаг. Тэгээд хуйларсан цасан шуурга өнгөрөн одсоны дараа байгалийн үзэсгэлэн гоог бахдах зуураа тэдний санаа амарч, тайвширдаг. Гэвч тийм мөчид хүнийг гэх хязгааргүй их хайрыг минь тэдний дундаас хэн ер нь туулсан бэ? Тэдний зүрх сэтгэлд Миний бие галбир л байхаас Миний Сүнсний мөн чанар байдаггүй: Хүн Намайг илт эсэргүүцэж байгаа бус уу? Хүчит шуурга өнгөрөн одоход бүх хүн төрөлхтөн яг л шинэчлэгдсэн

мэт, гай зовлонгоор цэвэршүүлэгдсэний дараа гэрэл болон амийг дахин олж авсан мэт байдаг. Миний цохьсон цохилтыг давсныхаа дараа та нар өнөөдөртэй золгох сайн аз завшаантай байсан бус уу? Гэхдээ өнөөдөр өнгөрч, маргааш болоход та нар аадар бороонь дараах цэвэр ариун чанараа хадгалж чадах уу? Та нар цэвэршүүлэлтийн дараах үнэнч байдлаа хадгалж чадах болов уу? Та нар өнөөдрийн дуулгавартай байдлаа хадгалж чадах уу? Үнэнч байдал чинь гуйвшгүй, хувиршгүй хэвээр байж чадах уу? Энэ нь хүний биелүүлэх чадвараас хэтэрсэн шаардлага мөн үү? Би өдөр бүр хүн төрөлхтний дунд амьдарч, тэдний дунд хүн төрөлхтөнтэй хамт үйлддэг боловч хэн ч, хэзээ ч анзаарч байгаагүй. Хэрэв Миний Сүнсний удирдамж байгаагүй бол бүх хүн төрөлхтнөөс хэн энэ эрин үед оршсоор байх байсан бэ? Хүмүүсийн дунд амьдарч, тэдэнтэй хамт үйлддэг гэж хэлэх үедээ Би дэгсдүүлж байгаа юм гэж үү? Өмнө нь Би: “Би хүн төрөлхтнийг бүтээж, залж чиглүүлж, бүх хүн төрөлхтнийг захирсан” гэж хэлсэн; үнэхээр тийм байгаагүй гэж үү? Эдгээр зүйлийг туулсан туршлага чинь хангалтгүй байх боломжтой юу? “Үйлчлэл үзүүлэгч” гэх ердийн нэг үгийг ухан ойлгоход бүх амьдрал чинь шаардагдана. Бодит туршлагагүйгээр хүн хэзээ ч Намайг мэдэж авахгүй, хэзээ ч Миний үгээр дамжуулан Намайг мэдэж авч чадахгүй. Гэхдээ өнөөдөр Би та нарын дунд биечлэн ирсэн—энэ нь та нарын ойлголтод илүү их ашиг тустай байх бус уу? Бие махбодтой болсон Би бас та нарын төлөөх аврал биш гэж үү? Хэрэв Би хүн төрөлхтний дунд Өөрийн үнэн биеэр бууж ирээгүй бол бүхий л хүн төрөлхтөн аль эрт үзэлд баригдчихсан, өөрөөр хэлбэл, Сатаны эзэмшил болчихсон байх байсан, учир нь чиний итгэдэг зүйл ердөө Сатаны дүр бөгөөд Бурхантай Өөртэй нь ямар ч хамаагүй. Энэ нь Миний аврал биш гэж үү?

Сатаныг Миний өмнө ирэхэд Би түүний зэрлэг догшин байдлаас айж ухардаггүй, бас үзэшгүй муухай байдлаас нь ч сүрддэггүй: Би зүгээр л үл ойшоодог. Сатан Намайг уруу татах үед Би түүний арга мэхийг нэвт харж, ичгүүр, гутамшигтайгаар сэмхэн зугтахад хүргэдэг. Сатан Надтай тулалдаж, Миний сонгосон хүмүүсийг булаахаар завдах үед Би Өөрийн махбодоор түүнтэй дайтдаг; бас Өөрийн махбодоор ардуудаа тэтгэж, хариулдаг, ингэснээр тэд хялбархан унаж, төөрөхгүй бөгөөд Би алхам бүрд нь тэднийг замчилдаг. Сатаныг ялагдан бууж өгөх үед Би Өөрийн ардуудын дунд алдрыг олж авсан байх болно, Миний ардууд сайхан, цангинасан гэрчлэлийг Надад хийсэн байх болно. Тиймээс Би Өөрийн удирдлагын төлөвлөгөөн дэх товойлгогчдыг авч, ёроолгүй нүх рүү нэгмөсөн доош хаяна. Энэ бол Миний төлөвлөгөө, Миний ажил. Амьдралдаа ийм нөхцөл байдалтай нүүр тулах өдөр чамд ирж болох юм: Чи дуртайяа Сатанд олзлуулахыг хүсэж байна уу, эсвэл Надаар авхуулах уу? Энэ бол чиний өөрийн хувь заяа бөгөөд чи үүнийг анхааралтай бодолцон үзэх ёстой.

Хаанчлалын амьдрал бол хүмүүсийн болон Бурханы Өөрийн амьдрал юм. Бүх хүн төрөлхтөн Миний халамж, хамгаалалтан дор оршиж, бүгд агуу улаан луутай хийх амь өрссөн тулаанд оролцдог. Энэхүү эцсийн тулаанд ялахын тулд, агуу

улаан лууг дуусгахын тулд бүх хүн бүхий л оршихуйгаа Миний хаанчлалд Надад өргөн барих ёстой. Энд ярьж байгаа “хаанчлал” гэдэг нь бурханлаг чанарын шууд засаглал дор амьдардаг амьдралыг хэлдэг бөгөөд тэнд Би, Миний сургалтыг шууд хүлээн авдаг бүх хүн төрөлхтнийг хариулдаг, ингэснээр тэдний амьдрал газар дээр байгаа хэдий ч тэнгэрт байгаа мэт—гурав дахь тэнгэр дэх амьдралын бодит биелэл байх юм. Хэдийгээр Би махбодод байгаа ч махбодын хязгаарлалтаас болж зовдоггүй. Маш олон удаа Би хүмүүсийн залбирлыг сонсохоор дунд нь орж, маш олон удаа хүмүүсийн дунд алхаж, магтаалд нь баяссан; хүмүүс Миний оршин тогтнолыг хэзээ ч мэддэггүй байсан ч гэсэн Би Өөрийн ажлыг мөн л ийм маягаар явуулдаг. Миний оршин суудаг газар бол Миний нуугддаг газар юм—ямартай ч Өөрийн оршин суудаг энэхүү газарт Би бүх дайснаа ялсан; Өөрийн оршин суудаг газартаа Би газар дээр амьдрах бодитой туршлагыг олж авсан; Өөрийн оршин суудаг газартаа Би хүний үг үйлдэл бүрийг ажиглаж, бүхий л хүн төрөлхтнийг харж хандаж, захирч байна. Хэрэв хүмүүс Миний санаа зорилгыг анхаарч, улмаар Миний зүрх сэтгэлийг хангалуун болгож, Намайг баясгах аваас Би бүх хүн төрөлхтнийг ерөөх нь гарцаагүй. Хүмүүсийн төлөө Миний зорьж буй зүйл энэ биш гэж үү?

Хүн төрөлхтөн комд орсон байгаа тул Миний аянгын нүргээнээр л зүүд нойрноосоо сэрдэг. Нүдээ нээх үедээ тэдний олонх нь эдгээр хүйтэн цацрагийн гэрэлд нүдээ гэмтээж, зүг чигээ олохгүйд хүрч, хаанаас ирснээ, хаашаа явж байгаагаа мэдэхгүй болдог. Ихэнх хүмүүс лазерынх мэт туяанд цохиулан, үр дүнд нь хүчит шуурган дор сулдайн унаж, тэдний цогцсыг ширүүн урсгал ямар ч ул мөр үлдээлгүй шүүрдэн зайлуулна. Гэрэлд, амьд үлдэгсэд эцэстээ Миний царайг маш тодорхой харж чаддаг болж, Миний гадаад төрхийн талаар ямар нэг юм мэдэж авч, цаашид Миний нүүр лүү эгцлэн харж зүрхлэхээ болиод, өөрсдийнх нь махан биеийг дахин хараж, гэсгээх вий хэмээн ихэд эмээдэг. Маш олон хүн орь дуу тавьж, гашуунаар мэгшин уйлдаг; маш олон хүн цөхрөлд автдаг; маш олон хүн цусаараа гол үүсгэдэг; маш олон хүн хүүр болж, ийш тийш зорилгогүй хөвдөг; маш олон хүн гэрэлд өөрийн байх газрыг олж, зүрх сэтгэлдээ гэнэтийн өвдөлт мэдэрч, олон жил аз жаргалгүй байсныхаа төлөө нулимс урсгадаг. Тун олон хүн гэрлийн шахалтаар бохир байдлаа улайж, өөрсдийгөө шинэчлэхээр шийддэг. Маш олон хүн сохорч, амьдрахын баяр хөөрийг аль хэдийн алдаж, улмаар гэрлийг анзаарах сөхөөгүй, зогсонги хэвээр үлдэж, төгсгөлөө хүлээдэг. Бас маш олон хүн амьдралын дарвуулаа дээш өргөж, гэрлийн удирдамж дор өөрсдийнхөө маргаашийг тэсэн ядан хүлээдэг… Өнөөдөр, хүмүүсийн дунд ийм байдалд эс орших хэн байна вэ? Миний гэрэлд эс орших хэн байна вэ? Чи хүчтэй байлаа ч, эсвэл сул дорой байлаа ч айсуй гэрлээс минь зайлсхийж яахан чадах билээ?

1992 оны 3 дугаар сарын 10

14-Р БҮЛЭГ

Эрин үеүдийн туршид нэг ч хүн хаанчлалд ороогүй, тиймээс хэн ч Хаанчлалын эрин үеийн нигүүлслийг эдлээгүй, хаанчлалын Хааныг ч хараагүй. Миний Сүнсний гэрэлтүүлэлт дор олон хүн хаанчлалын гоо үзэсгэлэнг зөгнөсөн мөртөө гадна талыг нь л мэддэг бөгөөд дотоод ач холбогдлыг нь мэддэггүй. Өнөөдөр хаанчлал газар дээр албан ёсоор оршин тогтнох үед дийлэнх хүн, Хаанчлалын энэ эрин үед яг юу гүйцэлдэхийг, хүмүүс эцэстээ ямар ертөнцөд очихыг мөн л мэддэггүй. Энэ тухайд хүн бүр будилж төөрөлдсөн байдалтай байх вий гэдгээс Би эмээж байна. Хаанчлал бүрэн гүйцэд биеллээ олох өдөр хараахан бүрэн ирээгүй учраас бүх хүн мунгинаж, үүнийг тодорхой ухаарч чаддаггүй. Хаанчлалын эрин үеийн хамтаар бурханлаг чанар дахь Миний ажил албан ёсоор эхэлдэг бөгөөд Хаанчлалын эрин үеийн албан ёсны энэхүү эхлэлийн хамтаар Миний зан чанар хүмүүст аажмаар харагдаж эхэлж байна. Тиймээс яг энэ мөчид л ариун бүрээ албан ёсоор дуугарч, бүгдэд тунхаглаж эхэлдэг. Би албан ёсоор эрх мэдлээ авч, хаанчлалд Хаан болон захирах үед Миний бүх ардууд яваандаа Надаар бүрэн төгс болгуулна. Дэлхийн бүх улс гүрэн хагаран бутрах яг тэр үед Миний хаанчлал бүрэлдэн тогтоно, бас тэр үед Би хувирч, бүхий л орчлон ертөнцтэй нүүр тулна. Тэр үед бүх хүн Миний алдар суут царайг харж, Миний жинхэнэ төрхийг нүдээр харна. Дэлхий ертөнцийг бүтээснээс хойш Сатан хүмүүсийг өнөөдрийн байгаа хэмжээнд хүртэл нь завхруулснаас эхлээд тэдний завхралаас үүдэн, тэдний үзэл бодлоор бол Би улам нууцлаг, улам бүр ойлгогдошгүй болсон. Хүмүүс Миний жинхэнэ нүүр царайг хэзээ ч харж байгаагүй, Надтай хэзээ ч шууд харилцаж байгаагүй. Зөвхөн цуу яриа, үлгэр домогт л хүний төсөөллийн “Би” байсан. Тиймээс хүмүүсийн оюун ухаанд буй “Өөрийгөө” шийдэж, маш олон жилийн турш тэдний өвөрлөсөн “Өөрийн” байр байдлыг өөрчлөх гэсэндээ Би хүний энэхүү төсөөлөл буюу хүний үзэлтэй нийцдэг. Энэ нь Миний ажлын зарчим билээ. Нэг ч хүн үүнийг нэгд нэггүй мэдэж чадаагүй. Хэдийгээр хүмүүс нүүрээрээ газар унан Надад мөргөж, Намайг шүтэн мөргөхөөр Миний өмнө ирсэн боловч Би хүмүүсийн ийм үйлдлийг таашаадаггүй, учир нь зүрх сэтгэлдээ тэд Миний дүрийг биш, харин Минийхээс өөр дүрийг тээдэг. Тиймээс, Миний зан чанарыг ойлгодоггүй учраас хүмүүс жинхэнэ нүүр царайг минь огт таньдаггүй. Үүний үр дүнд, Намайг эсэргүүцсэн юм уу Миний захиргааны зарлигийг зөрчсөн хэмээн тэднийг бодох үед Би мөн л хараагүй дүр үзүүлдэг—тиймээс тэдний ой санамжид Би бол хүмүүсийг гэсгээхийн оронд өршөөдөг Бурхан, эсвэл хэлсэндээ хүрдэггүй Бурхан Өөрөө юм. Эдгээр нь бүгд хүний бодлоос гарсан төсөөлөл бөгөөд бодит баримттай нийцдэггүй.

Би өдөр бүр орчлон ертөнцийг ажиглан зогсож, амьдран суудаг газартаа даруухнаар нуугдан, хүний амьдралыг туулж, хүмүүсийн үйл хэрэг бүрийг сайтар судалдаг. Хэн ч, хэзээ ч Надад өөрийгөө үнэхээр өгөөгүй; хэн ч, хэзээ ч үнэнийг эрэлхийлээгүй. Хэн ч, хэзээ ч Надад ухамсартай хандаж, Миний өмнө шийдвэр

гаргаад, дараа нь үүргээ биелүүлж байсангүй. Хэн ч, хэзээ ч Надад дотор нь оршихыг зөвшөөрч байсангүй, Намайг өөрсдийнхөө амь шиг эрхэмлэж ч байсангүй. Бодит байдал дээр хэн ч, хэзээ ч Миний бурханлаг чанар бүхэлдээ юу болохыг хараагүй; хэн ч, хэзээ ч бодитой Бурхантай Өөртэй нь холбоотой байхыг хүсээгүй. Ус хүмүүсийг бүхлээр нь залгих үед Би тэднийг тогтоол уснаас аварч, шинээр амьдрах боломж өгдөг. Хүмүүс амьдрах итгэлээ алдах үед Би тэднийг үхлийн ирмэгээс татан авч, цааш явах зориг өгч, Намайг оршин тогтнолынхоо үндэс болгон ашиглах боломж олгодог. Хүмүүс Надад дуулгаваргүй байх үед дуулгаваргүй байдлаас нь Би Өөрийгөө тэдэнд мэдүүлдэг. Хүний хуучин уг чанарыг харгалзан үзээд, мөн Өөрийн өршөөлийг харгалзан үзээд Би хүмүүсийг цаазаар авахын оронд гэмшиж, шинээр эхлэх боломж олгодог. Тэднийг өлсгөлөнд нэрвэгдэх үед биед нь эцсийн ганц амьсгал үлдсэн байлаа ч Би тэднийг үхлээс булаан авч, Сатаны заль мэхэнд урхидуулахаас сэргийлдэг. Хүмүүс Миний гарыг маш олон удаа харж, Миний эелдэг төрх, инээмсэглэсэн царайг маш олон удаа харж, Миний сүр жавхлан, уур хилэнг маш олон удаа харсан. Хүмүүс Намайг хэзээ ч мэдээгүй боловч Би зориуд өдөөн хатгах гэж сул талыг нь ашигладаггүй. Хүний зовлон зүдгүүрийг туулаад Би хүний сул талыг өрөвдөх болсон. Хүмүүсийн дуулгаваргүй байдал, ач мэддэггүй зангийн хариуд л Би өөр өөр түвшний гэсгээлт оноодог.

Хүмүүсийг завгүй байхад Би Өөрийгөө нууж, зав чөлөөтэй үед нь Өөрийгөө илчилдэг. Хүмүүс Намайг бүхнийг мэддэг гэж төсөөлдөг; тэд Намайг бүх гуйлтыг зөвшөөрдөг Бурхан Өөрөө гэж үздэг. Тиймээс дийлэнх нь Намайг мэдье гэсэн хүслээс болж биш, зөвхөн Бурханаас тусламж эрэхээр л Миний өмнө ирдэг. Өвдөж шаналах үедээ хүмүүс Миний тусламжийг шаргуу гуйдаг. Гай зовлонгийн цагт, зовлонгоосоо салахын тулд өөрсдийн бэрхшээлийг Надад бүх чадлаараа аминчлан хэлдэг. Гэвч тав тухтай байхдаа ганц ч хүн Намайг бас л хайрлаж чадаагүй; амар амгалан, аз жаргалтай байх үедээ баяр баясгалангаа хуваалцахаар ганц ч хүн Надад хандаагүй. Бяцхан гэр бүл нь аз жаргалтай, сайн сайхан байх үед хүмүүс Намайг аль хэдийн орхих юм уу Миний өөдөөс хаалгаа хааж, гэр бүлийнхээ ерөөгдсөн аз жаргалыг өөрсдөө эдлэх гэсэндээ Намайг орохыг хориглодог. Хүний оюун санаа хэтэрхий явцуу; Над шиг элэгсэг, өршөөнгүй, хүрч болох Бурханыг ч багтаахааргүй явцуу. Хүмүүс баяр хөөртэй инээж байх үедээ Намайг маш олон удаа голсон; хүмүүсийг төөрөлдөн бүдчиж явахад нь Би маш олон удаа тэдний тулдаг таяг болсон; өвчинд шаналж байгаа хүмүүст Би маш олон удаа эмчийн үүрэг гүйцэтгэхээс аргагүй болсон. Хүмүүс хэчнээн харгис юм бэ! Тэд үнэхээр эрүүл ухаангүй, ёс суртахуунгүй. Хүмүүст байх учиртай мэдрэмжүүдийг ч тэднээс харах аргагүй; тэдэнд хүн чанарын ул мөр бараг огт байдаггүй. Өнгөрснийг тунгаан бодож, одоо үетэй харьцуул: Та нарын дотор ямар нэгэн өөрчлөлт гарч байна уу? Өнгөрсөн үеийнхээ зарим зүйлээс салсан уу? Эсвэл тэрхүү өнгөрсөн үе хараахан солигдоогүй байна уу?

Би уул нурууд, голын хөндийгөөр хөндлөн гулд явж, хүний ертөнцийн сайн, муут туулаа. Хүмүүсийн дундуур Би хэрэн хэсэж, тэдний дунд олон жил амьдарсан

атал хүмүүсийн зан чанар багахан өөрчлөгдсөн мэт харагддаг. Хүмүүсийн хуучин уг чанар дотор нь үндэслэж, нахиалсан мэт байдаг. Тэд тэрхүү хуучин уг чанараа хэзээ ч өөрчилж чаддаггүй; тэд үүнийг анхдагч суурин дээр нь л ялимгүй сайжруулдаг төдий. Хүмүүсийн хэлдгээр гол чанар нь өөрчлөгдөөгүй, харин хэлбэр нь ихээхэн өөрчлөгджээ. Хүмүүс бүгд Намайг хуурч, будилуулан, зальдаад Миний сайшаалыг хүртэх гэж байгаа мэт санагддаг. Би хүний заль мэхийг шагшин бахаддаг ч үгүй, анхаарлаа хандуулдаг ч үгүй. Хилэгнэн уурлахын оронд, харсан ч үзэхгүй байх хандлага баримталдаг. Би хүмүүст тодорхой хэмжээний эрх чөлөө олгож, дараа нь бүх хүнд хамтад нь харьцалт хийхээр төлөвлөдөг. Хүмүүс бүгд өөрсдийгөө хайрладаггүй, өөрсдийгөө огт нандигнадаггүй, үнэ цэнгүй өөдгүй амьтад байхад Би яагаад ер нь тэдэнд дахин нэг удаа өршөөл, хайр үзүүлэх хэрэгтэй юм бэ? Хүмүүс бүгдээрээ өөрсдийгөө мэддэггүй, хэр үнэ цэнтэйгээ ч мэддэггүй. Тэд жингээ үзэхийн тулд жинлүүр дээр өөрсдийгөө тавих ёстой. Хүмүүс Намайг ер хайхардаггүй тул Би ч бас тэднийг нухацтай авч үздэггүй. Тэд Надад ямар ч анхаарал хандуулдаггүй тул Би ч гэсэн тэдэн дээр шаргуу ажиллах хэрэггүй. Энэ нь хоёуланд нь хамгийн сайн биш гэж үү? Энэ нь та нарыг дүрсэлдэг бус уу, Миний ардууд аа? Та нарын дундаас хэн Миний өмнө шийдвэр гаргачихаад дараа нь түүнийгээ хаяагүй вэ? Хэн байн байн шийдвэр гаргахын оронд Миний өмнө урт хугацааны шийдвэр гаргасан бэ? Хүмүүс амар тайван байх үедээ Миний өмнө дандаа шийдвэр гаргаад, гай зовлонгийн цагт тэдгээрийг бүгдийг нь хүчингүй болгодог; тэгээд дараа нь шийдвэрээ дахин барьж аваад, Миний өмнө тавьдаг. Би овоолсон хогоос хүмүүсийн түүсэн энэ хаягдлыг хээгүй хүлээгээд авчихмаар тийм хүндлээд байхааргүй Нэгэн юм уу? Цөөхөн хүн л шийдвэрээ бат хадгалдаг, цөөн хэд нь цэвэр ариун байдаг ба цөөхөн хүн өөрсдөд нь хамгийн эрхэм зүйлийг тахил болгон Надад өргөдөг. Та нар бүгд адилхан бус уу? Хаанчлал дахь Миний ардуудын нэг гишүүн болохын хувьд хэрвээ та нар үүргээ биелүүлж чадахгүй бол Надад жигшигдэн гологдоно!

1992 оны 3 дугаар сарын 12

15-Р БҮЛЭГ

Хүмүүс бүгд өөрсдийгөө таних чадваргүй бүтээлүүд бөгөөд өөрсдийгөө мэдэж чаддаггүй. Гэсэн ч бусдын хийсэн, хэлсэн бүхэн эхлээд яг тэдний өмнө “шалгуулж”, хийгдэхээсээ өмнө тэдний зөвшөөрлийг авсан мэт тэд бусад бүх хүнийг гарын арван хуруу шигээ мэддэг. Үүний үр дүнд, тэд бусад бүх хүний сэтгэл санааны байдлыг нь хүртэл бүрэн дүүрэн үнэлсэн мэт байдаг. Хүмүүс бүгд ийм. Өнөөдөр тэд Хаанчлалын эрин үед орсон хэдий ч уг чанар нь өөрчлөгдөлгүй үлддэг. Тэр Миний өмнө Миний хийдэг зүйлийг хийдэг, харин ар хударгаар минь өөрсдийн

онцгой “бизнесийг” явуулж эхэлдэг. Гэвч дараа нь Миний өмнө ирэх үедээ тэд шал өөр хүмүүс шиг, харваас амирлангуй, айдасгүй, тайван амгалан царайтай, судасны цохилт нь жигдхэн байдаг. Хүмүүсийг жигшүүртэй болгодог зүйл яг энэ биш гэж үү? Маш олон хүн шал өөр хоёр нүүр гарган—Миний өмнө байхдаа нэг, Миний ар хударгаар өөр нэг дүр эсгэдэг. Маш олон хүн Миний өмнө дөнгөж төрсөн хурга шиг аашилдаг мөртөө Миний ар хударгаар догшин бар болон хувирч, дараа нь уул толгодоор цовоо хөгжүүн нисэж байгаа бяцхан шувуу шиг авирладаг. Тун олон хүн Миний өмнө шийдвэрээ харуулдаг. Үнэхээр олон Миний үгээр цангаж, Миний үгийг хүсэмжлэн эрэлхийлж Миний өмнө ирдэг ч Миний ардуур Миний үгээс залхаж, Миний айлдваруудыг садаа тээр мэт хаядаг вэ? Дайсныхаа завхруулсан хүн төрөлхтнийг өчнөөн олон удаа хараад Би хүмүүст найдлага тавихаа больсон. Хүмүүс Миний өмнө ирж, нулимс урсган өршөөл гуйхыг өчнөөн олон удаа хараад Би, өөрийгөө хүндэлдэггүй, зөрүүд засаршгүй зангаас нь болоод тэдний зүрх сэтгэл жинхэнэ, санаа зорилго нь чин үнэнч байхад ч гэсэн тэдний үйлдэлд уурсан нүдээ аньсан. Надтай хамтран ажиллах итгэлтэй, Миний өмнө байхдаа Миний тэвэрт байгаа мэт, халуун дулаан байдлыг амсдаг хүмүүсийг Би олон удаа харсан. Өөрийн сонгосон хүмүүсийнхээ гэм зэмгүй, цовоо цолгин, сэтгэл татам байдлыг маш олон удаа хараад эдгээрийг асар их таашаахгүй байж Би яахан чадах билээ? Хүмүүс Миний гараар урьдчилан тогтоогдсон ерөөлөө хэрхэн эдлэхээ мэддэггүй, учир нь тэд “ерөөл” болон “зовлон” гэдэг нь хоёулаа яг юу гэсэн үг болохыг ойлгодоггүй. Энэ шалтгааны улмаас, хүмүүс Намайг эрж хайхдаа огтхон ч чин сэтгэлээсээ ханддаггүй. Хэрвээ маргааш гэж байдаггүй байсан бол Миний өмнө зогсож байгаа та нараас хэн чинь орж буй цас шиг цэвэр, хаш мэт сэвгүй байх байсан бэ? Намайг гэх хайр чинь амттай хоолоор, ганган хувцсаар, эсвэл цалин хөлс сайтай албан тушаалаар сольж болдог зүйл юм гэж үү? Үүнийг бусад хүмүүсийн чамайг гэх хайраар сольж болох уу? Шалгалт туулах нь үнэндээ Намайг гэсэн хайраа орхиход хүмүүсийг хүргэх юм гэж үү? Зовлон шаналал, гай гамшиг нь тэднийг Миний зохицуулалтын талаар гомдоллоход хүргэх үү? Миний аман дахь хурц илдийг хэн ч, хэзээ ч үнэхээр ойлгоогүй: Тэд энэ нь юунд хүргэдгийг үнэхээр ухааралгүйгээр зөвхөн өнгөц утгыг нь л мэддэг. Хэрвээ хүмүүс Миний илдний хурцыг үнэхээр харж чаддаг байсан бол харх адилаар нүх рүүгээ яаран харайлдах байсан юм. Хөшүүн байдлаасаа болоод хүмүүс Миний үгийн жинхэнэ утга учрын юуг ч ойлгодоггүй тул Миний айлдварууд хэчнээн сүрдмээр болохыг, эсвэл тэдгээр нь хүний уг чанарыг яг хэр их илчилдгийг, бас тэдгээр үг өөрсдийнх нь завхралыг хэр их шүүдгийг огт мэддэггүй. Ийм учраас, Миний хэлдэг зүйлийг дутуу дулимаг ойлгосноос үүдэн ихэнх хүн хайхрамжгүй хандлага баримталсан.

Хаанчлалын дотор Миний амнаас айлдвар гараад зогсохгүй, Миний хөл бүх газар нутаг даяар хаа сайгүй албан ёсоор алхалдаг. Ийм маягаар Би бүх бузар заваан газрыг ялан дийлсэн, ингэснээр зөвхөн тэнгэр өөрчлөгдөж байгаагаар зогсохгүй, бас газар ч өөрчлөгдөх явцдаа байгаа ба дараа нь шинэчлэгдэнэ.

Сансар огторгуй дотор Миний алдрын гэрэлд бүх зүйл шинэ мэт гялалзан, сэтгэл бахдуулж, хүмүүсийн сэтгэл санааг өргөм хөөр баяртай талыг харуулж, хүний төсөөлөл дэх Сатаны хөндлөнгийн оролцоогүй, гаднын дайснуудын халдлагаас ангид тэнгэрүүдийн цаадах тэнгэрт одоо оршин байгаа мэт байдаг. Орчлон ертөнцийн хамгийн дээд хүрээнд тоо томшгүй од Миний тушаалаар өөрсдөд нь оногдсон байрыг эзэлж, түнэр харанхуйн цагаар одот тэнгэрийг гэрэлтүүлдэг. Ганц ч оршихуй гөжүүд бодол өвөрлөж зүрхэлдэггүй тул Миний захиргааны зарлигийн гол чанарын дагуу бүхий л ертөнц сайтар зохицуулагдаж, төгс дэг журамтай байдаг: Ямар нэг үймээн самуун хэзээ ч гараагүй, сансар огторгуй ч хэзээ ч хуваагдаагүй. Би од мичдийн дээгүүр дүүлэн харайж, нар цацрагаа илгээх үед дулааныг нь сарниулж, галууны өд шиг том цасан ширхгийг гараасаа унагасан. Гэхдээ Намайг бодлоо өөрчлөхөд тэр бүх цас гол болон хайлаад, агшин зуур тэнгэрийн дор хаа сайгүй хавар болж, маргад ногоон өнгө газрын гадаргыг тэр чигт нь хувиргасан. Намайг огторгуй дээгүүр хэрэн явахад Миний биеэс болоод газар дэлхийг тэр даруй түнэр харанхуй нөмөрдөг: Ямар ч сануулгагүйгээр “шөнө” болсон ба дэлхий даяар, гараа нүүрнийхээ өмнө аваачаад ч харж чадахааргүй тийм харанхуй болсон. Гэрэл бөхөхөд хүмүүс энэ боломжийг ашиглан нэг нэгнээ сүйрүүлэхээр улайрч, бие биеэсээ булаан дээрэмддэг. Тэгээд газар дэлхийн улс үндэстнүүд эмх замбараагүй хагаралд хүрч, аврагдах аргагүй болтлоо ороо бусгаа байдалд ордог. Хүмүүс зовлон шаналлын тарчлаан дунд тэмцэлдэж, шаналлынхаа дунд ёолон гасалж, тарчилсандаа хөөрхийлөлтэйгөөр уйлж, хүний ертөнцөд гэрэл гэнэт дахин нэгэнтээ ирээд, улмаар харанхуй өдрүүдийг төгсгөж, нэгэн цагт оршин байсан амин чанарыг сэргээгээсэй хэмээн хүсэн эрмэлздэг. Гэвч Би аль хэдийн хүмүүсийг ханцуйгаараа шавхуурдаад орхисон ба дэлхийн шударга бус байдлаас болж хэзээ ч тэднийг өрөвдөхгүй: Би бүх дэлхийн хүмүүсийг аль хэдийн жигшин голж, тэндхийн нөхцөл байдлыг нүдээ анин үл тоож, хүмүүсийн хөдөлгөөн, дохио зангаа бүрээс нүүр буруулсан ба тэдний балчир нас болон гэмгүй занд сэтгэл баясахаа больсон. Дэлхийг шинэчлэх өөр төлөвлөгөөг Би эхлүүлсэн, ингэснээр энэхүү шинэ дэлхий аль болох хурдан сэргэн мандаж, дахин хэзээ ч живэхгүй байх юм. Хүмүүсийн дунд, маш олон хачин жигтэй байдал засаж залруулахыг минь хүлээж байна, Миний биечлэн сэргийлэх маш олон алдаа байна, мөн Миний шүүрдэж арилгах тоос тун их бий, Миний илчлэх ёстой маш олон нууц бий. Бүх хүн Намайг хүлээж, Миний ирэхийг хүсэмжилж байна.

Газар дээр бол Би хүмүүсийн зүрх сэтгэлд оршдог бодитой Бурхан Өөрөө; тэнгэрт бол Би бүх бүтээлийн Эзэн. Би ууланд авирч, гол мөрнийг гаталсан ба хүмүүсийн дунд хаа сайгүй явсан. Бодитой Бурханыг Өөрийг нь хэн илт эсэргүүцэж зүрхлэх юм бэ? Төгс Хүчитийн дээд эрхээс хэн ангижирч зүрхлэх юм бэ? Намайг тэнгэрт байдаг гэж ямар ч эргэлзээгүйгээр хэн баталж зүрхлэх юм бэ? Түүнчлэн, Намайг газар дээр маргаангүй байдаг гэж хэн баталж зүрхлэх юм бэ? Бүх хүний дундаас Миний оршин суудаг газруудыг нарийвчлан тодорхой өгүүлж чадах хэн ч

үгүй. Тэнгэрт байх болгондоо Би ер бусын Бурхан Өөрөө бөгөөд газар дээр байх болгондоо бодитой Бурхан Өөрөө юм гэж үү? Мэдээж бүх бүтээлийн Захирагч гэдгээр минь, эсвэл Би хүний ертөнцийн зовлон шаналлыг туулдаг гэх баримтаар бодитой Бурхан Өөрөө мөн эсэхийг минь тодорхойлж болохгүй биз дээ? Хэрвээ тэгдэг байсан бол хүмүүс ямар ч найдваргүй мунхаг байх бус уу? Би тэнгэрт байдаг, Би бас газар дээр байдаг; Би тоо томшгүй олон бүтээгдсэн зүйлийн дунд байдаг, бас олон түмний дунд байдаг. Хүмүүс Надад өдөр бүр хүрч чадна; түүнчлэн тэд Намайг өдөр бүр харж чадна. Хүмүүсийн тухайд бол Би заримдаа нуугдаж, заримдаа үзэгдэж байгаа мэт санагддаг; Би үнэхээр оршин байгаа мэт атлаа бас оршдоггүй мэт санагддаг. Хүмүүсийн ойлгошгүй нууцууд Надад оршдог. Надад байдаг бүр ч их нууцыг нээн илрүүлэхийн тулд бүх хүн Намайг микроскопоор харж, тэгснээрээ өөрсдийн зүрх сэтгэл дэх таагүй мэдрэмжүүдийг арилгана гэж найдаж байгаа мэт байдаг. Гэхдээ хүмүүс рентген туяа ашигласан ч гэсэн Надад байдаг нууцуудын аль нэгийг нээн илрүүлж яахан чадах билээ?

Миний ажлын үр дүнд Миний ардууд Надтай хамт алдрыг олж авах яг тэр үед агуу улаан лууны ичээг ухан гаргах болно, бүх шавар шороог шүүрдэн цэвэрлэж, тоймгүй олон жилийн турш хуримтлагдсан бохир ус Миний дүрэлзсэн галд хатаж, цаашид оршин байхаа болино. Тэгээд агуу улаан луу гал ба хүхэртэй нууранд мөхөх болно. Та нар лууд баригдахгүйн тулд Миний хайр халамжин дор үлдэхийг үнэхээр хүсэж байна уу? Та нар түүний зальхай ов мэхийг үнэхээр үзэн яддаг уу? Хэн Миний төлөө хүчирхэг гэрчлэл хийж чадах вэ? Миний нэрийн төлөө, Миний Сүнсний төлөө, Миний бүх удирдлагын төлөвлөгөөний төлөө хэн бүх хүч чадлаа зориулж чадах вэ? Өнөөдөр, хаанчлал хүний ертөнцөд байгаа үе бол Би хүмүүсийн дунд биечлэн ирсэн үе юм. Хэрвээ ийм байгаагүй бол Миний оронд тулааны талбар луу айдас хүйдэсгүйгээр орж чадах нэгэн байна уу? Хаанчлал хэлбэрээ олог гэж, Миний зүрх сэтгэл хангалуун байг гэж, тэгээд бас Миний өдөр ирэг гэж, бүтээлийн тоо томшгүй олон зүйл дахин төрж, элбэг дэлбэг болон өсөх цаг ирэг гэж, хүмүүс зовлонгийн далайгаас аврагдаг гэж, маргааш ирэг гэж, тэр нь гайхалтай байж, хөгжин цэцэглэг гэж, бас ирээдүйд баяр хөөртэй байг гэж бүх хүн хамаг чадлаараа чармайж, юугаа ч гамналгүй Миний төлөө өөрсдийгөө золиосолж байна. Энэ нь ялалт аль хэдийн Минийх гэдгийн тэмдэг биш гэж үү? Миний төлөвлөгөө биелсний тэмдэг биш гэж үү?

Хүмүүс эцсийн өдрүүдэд орших тусмаа, дэлхий ертөнцийн хоосон байдлыг улам их мэдэрч, амьдрах зориг нь улам бага байх болно. Ийм учраас, тоо томшгүй олон хүн урам хугаран нас барсан, тоймгүй олон бусад хүн эрэл хайгуулдаа урам нь хугарч, тоо томшгүй олон хүн Сатаны явуулгад автаж өөрсдийгөө зовоосон. Би маш олон хүнийг аварч, маш олон хүнийг дэмжсэн ба маш олон удаа хүмүүсийг гэрлээ алдах үед гэрэл дотор Намайг мэдэж, аз жаргалын дунд Намайг таашааг гээд Би тэднийг буцаагаад гэрэлтэй газарт аваачсан. Миний гэрэл ирснээс болоод Миний хаанчлалд оршин суудаг хүмүүсийн зүрх сэтгэлд хүндлэл бишрэл бий

болдог, учир нь Би бол хүмүүсийн хайрлах Бурхан, хүмүүсийн салж чадахааргүй дассан Бурхан бөгөөд тэд Миний биеийн талаар гүн гүнзгий сэтгэгдлээр бялхдаг. Гэхдээ эцсийн эцэст, энэ нь чухамдаа Сүнсний ажил уу, эсвэл бие махбодын чиг үүрэг үү гэдгийг ойлгодог хүн нэг ч үгүй. Хүмүүс насан туршдаа нэгд нэггүй туулахад энэ нэг зүйл дангаараа хангалттай юм. Хүмүүс зүрх сэтгэлийнхээ гүнд Намайг хэзээ ч жигшиж байгаагүй; харин ч сүснийхээ гүнд тэд Надаас салж яддаг билээ. Миний мэргэн ухаан тэдний бахдал бишрэлийг төрүүлж, Миний үзүүлдэг гайхамшгууд тэдний нүдийг хужирлаж, Миний үг тэдний санаанд багтамгүй байдаг ч тэд тэдгээрийг нандигнан хайрладаг. Миний бодит байдал хүмүүсийг самгардуулж, мэл гайхуулж, алмайруулдаг хэр нь тэд үүнийг хүлээж авахад бэлэн байдаг. Энэ нь чухамдаа хүмүүсийн жинхэнэ биеийн хэмжээ биш гэж үү?

1992 оны 3 дугаар сарын 13

16-Р БҮЛЭГ

Хүнд Миний хэлэхийг хүсдэг зүйл маш их бөгөөд түүнд хэлэх ёстой зүйл маш олон бий. Гэвч хүний хүлээн авах чадвар хэтэрхий дутуу дулимаг; хүн Миний үгийг Миний өгсний дагуу бүрэн ухаарах чадваргүй ба зөвхөн нэг талыг нь л ойлгохын сацуу нөгөөг нь мэдэхгүй хэвээр үлддэг. Гэсэн ч Би хүчин мөхөс байдлаас нь болж хүнийг үхүүлдэггүй, мөн сул доройгоос нь болж гонсойдоггүй. Хүн Миний хүслийг ойлгодоггүй ч гэсэн Би ердөө л Өөрийн ажлыг хийж, урьдын адилаар үгээ хэлдэг; цаг нь ирэхэд хүмүүс Намайг зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэж, бодолдоо Намайг дурсан санана. Би энэ дэлхийгээс явах үе бол Би хүний зүрх сэтгэл дэх сэнтийд залрах яг тэр үе байх болно, өөрөөр хэлбэл, энэ нь бүх хүн Намайг мэдэх үе байх болно. Тиймээс энэ нь бас Миний хөвгүүд болон ардууд албан ёсоор газар дээр засаглах үе байх болно. Намайг мэддэг хүмүүс гарцаагүй Миний хаанчлалын багана болох ба зөвхөн тэд л Миний хаанчлалд засаглаж, эрх мэдэл эзэмшихэд тохирно. Намайг мэддэг хүмүүс бүгд Миний оршихуйг эзэмшдэг бөгөөд бүх хүний дунд Намайг амьдран харуулж чаддаг. Хүн Намайг хэр зэрэг мэддэгийг Би тоодоггүй: Ямар ч байсан хэн ч Миний ажилд саад хийж чадахгүй ба хүн Надад ямар ч тусламж үзүүлж, юу ч хийж өгч чадахгүй. Хүн Миний гэрэлд Миний удирдамжийг дагаж, энэ гэрэлд Миний хүслийг эрж хайж л чадна. Өнөөдөр хүмүүс чадвартай болсон ба Миний өмнүүр маадайн алхаж, Надтай огтхон ч эрээ цээргүй инээж, марзганан, Надтай ижил зиндааных мэт харилцаж болно гэж боддог. Хүн Намайг бас л мэддэггүй, бид уг чанартаа адилхан, хоёулаа мах, цуснаас бүтсэн, хоёулаа хүний ертөнцөд оршдог гэж бодсоор байдаг. Намайг хүндлэх түүний хүндлэл хэтэрхий хомс; Миний өмнө байхдаа Намайг хүндэлдэг боловч Сүнсний өмнө Надад үйлчлэх чадваргүй. Хүний хувьд Сүнс огт оршдоггүй юм шиг л байдаг.

Үр дүнд нь хэн ч, хэзээ ч Сүнсийг мэдээгүй; бие махбодтой болсон Надаас хүмүүс мах, цуснаас бүрдсэн биеийг л хардаг боловч Бурханы Сүнсийг хардаггүй. Ийм маягаар Миний хүслийг биелүүлж үнэхээр чадах уу? Хүмүүс Намайг мэхлэхдээ гарамгай; Намайг хуурахын тулд Сатан тэднийг тусгайлан сургасан мэт санагддаг. Гэсэн ч Би Сатаны үймээнд автдаггүй. Өөрийн хаанчлалыг газар дээр байгуулахын тулд Би мэргэн ухаанаа ашиглан бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүх хүн төрөлхтнийг завхруулагчийг ялна.

Хүмүүсийн дунд, оддын хэмжээг, эсвэл орон зайн цараг магадлан мэдэх гэж оролдсон хүмүүс бий. Гэсэн ч тэдний судалгаа хэзээ ч үр дүнтэй байгаагүй, тэд урам хугаран толгойгоо гудайлгаж, бүтэлгүйтлээ зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрдэг. Бүх хүнийг харж, хүний бүтэлгүйтлийн хөдөлгөөнийг ажиглаад хэн нь ч Надад бүрэн үнэмшдэггүй, хэн нь ч Надад дуулгавартай байж, Надад захирагддаггүй гэдгийг Би хардаг. Хүний санаархал хэчнээн цадиггүй вэ! Оёоргүй гүний гадаргуу бүхэлдээ булингартсан байхад хүмүүсийн дунд Би дэлхий ертөнцийн гашуун зовлонг амсаж эхэлсэн. Миний Сүнс дэлхий даяар аялж, бүх хүний зүрх сэтгэлийг шинждэг, гэхдээ Би бас Өөрийн махбод болсон биеэр хүн төрөлхтнийг байлдан дагуулдаг. Хүн сохор учраас Намайг хардаггүй; хөшүүн болсон учраас Намайг мэддэггүй; дуулгаваргүй учраас Намайг эсэргүүцдэг; Надаар байлдан дагуулагдсан учраас Миний өмнө ирж сөгддөг; Би угаасаа хүний хайрыг хүртвэл зохих учраас хүн Намайг хайрлаж эхэлдэг; Миний хүч чадал болон мэргэн ухаан хүнийг Миний зүрх сэтгэлийн дагуу болгодог учраас тэрээр Намайг амьдран харуулж, Намайг илэрхийлдэг. Би хүний зүрх сэтгэлд зай эзэлдэг боловч сүнсэнд нь буй Намайг гэсэн хайрыг хэзээ ч хүлээн авч байгаагүй. Хүний сүнсэнд бүхнээс дээдлэн хайрладаг зүйлс үнэхээр байдаг боловч Би тэдгээрийн нэг нь биш тул хүний хайр савангийн хөөстэй адил: Салхи үлээхэд хагараад, хэзээ ч дахин үзэгдэхгүйгээр алга болдог. Би хүнд хандахдаа үргэлж тууштай, хувиршгүй байсаар ирсэн. Хүн төрөлхтний дунд ингэж чадсан хүн бий юу? Хүний нүдэнд Би агаар мэт мэдрэгдэшгүй, харагдашгүй байдаг ба ийм учраас дийлэнх хүмүүс хязгааргүй тэнгэр, давлагаалах далай тэнгис, дөлгөөн нуур, аль эсвэл хоосон бичиг үсэг, номлол дундаас л эрж хайдаг. Хүн төрөлхтний мөн чанарыг мэддэг ганц ч хүн байхгүй, Миний доторх нууцын талаар ямар нэгэн зүйл хэлж чадах хүн бүр ч байхгүй тул, иймээс Би хүний төсөөлдөг шигээр хамгийн өндөр стандартад хүрэхийг түүнээс шаарддаггүй.

Миний үгийн дунд уулс нуран унаж, ус сөрөн урсаж, хүн дуулгавартай болж, нуур зогсолтгүй урсаж эхэлдэг. Хэдийгээр давлагаалах далайн давлагаа тэнгэр өөд ууртай тэмүүлдэг ч Миний үгийн дунд тийм далай нуурын гадаргуу мэт тогтуун болдог. Миний гар ялимгүй дохих төдийд догшин шуурга төдхөн замхарч, Надаас холддог ба хүний ертөнц нам гүм байдалдаа даруйхан эргэж ордог. Гэвч Миний уур хилэн бадрахад уулс тэр даруй хагаран хуваагдаж, газар тэр даруй доргин чичирч, ус нэн даруй ширгэж, хүнийг гай гамшиг даруй хүрээлдэг. Өөрийн уур хилэнгээс

болж Би хүний хашхирааныг ойшоодоггүй, Миний уур ихсэж байгаа учир хүнийг уйлж хашхирахад нь тусламж үзүүлдэггүй. Намайг тэнгэрүүдийн дунд байхад Миний байгаагаас болж одод хэзээ ч сандарч байгаагүй. Харин тэд зүрх сэтгэлээ Миний төлөөх ажилдаа зориулдаг, тиймээс Би тэдэнд илүү их гэрэл хайрлаж, илүү тод гялалзуулдаг, ингэснээр тэд Миний төлөө илүү их алдрыг олж авдаг. Тэнгэрүүд гэрэлтэй байх тусам доорх газар дэлхий төдий чинээ харанхуй байдаг; маш олон хүн Миний зохицуулалтыг тохиромжгүй хэмээн гомдоллосон, маш олон хүн Надаас урвахдаа хэрэглэх өөрсдийн хаанчлалыг байгуулж, харанхуй байдлыг өөрчлөх гээд Намайг орхисон. Гэхдээ өөрсдийн шийдвэрээр үүнийг хийж чадсан хэн байна вэ? Хэн өөрийнхөө шийдвэрт амжилт олсон бэ? Хэн Миний гараар зохицуулсан зүйлийг өөрчилж чадах вэ? Газар нутаг даяар хавар ирэхэд Би дэлхий рүү нууцаар, чимээгүйхнээр гэрэл илгээдэг, ингэснээр газар дэлхий дээр хүн цэнгэг агаарыг гэнэт мэдэрдэг. Гэсэн ч яг тэр мөчид Би хүний нүдийг халхалдаг, ингэснээр тэр зөвхөн хаа сайгүй бүрхсэн мананг хардаг бөгөөд бүх хүн, юмс бүдэг бадаг үзэгддэг. Хүмүүс гагцхүү шүүрс алдан, “Гэрэл яагаад ганцхан хором үргэлжлэв ээ? Бурхан яагаад хүнд зөвхөн манан, будан өгдөг юм бэ?” хэмээн боддог. Хүмүүсийг цөхөрч байхад манан тэр дороо арилдаг боловч гэрэл сүүмэлзэхийг анзаарах үед нь Би тэдэн дээр аадар бороо оруулдаг бөгөөд тэднийг унтаж байхад аянгын дуу чихнийх нь хэнгэргийг хагалдаг. Айж мэгдсэндээ болоод тэд хоргодох газар олж амжилгүй, аадар бороонд шалба нордог. Агшин зуур тэнгэрийн доорх бүх зүйл Миний уур хилэн дунд угаагдан цэвэрлэгддэг. Хүмүүс ширүүн борооны талаар гомдоллохоо больж, тэдний дотор хүндлэл төрдөг. Энэхүү гэнэтийн ширүүн бороноос болж хүмүүсийн дийлэнх олонх нь тэнгэрээс буусан усанд живж, усан дотор цогцос болдог. Би дэлхийг бүхэлд нь ажиглан, олон хүн сэрж байгааг, олон хүн гэмшиж, олон хүн жижиг завиндаа суугаад усны эх сурвалж хайж байгааг, олон хүн Надаас уучлал гуйн Надад мэхийж байгааг, олон хүн гэрэл харсныг, олон хүн Миний царайг харсныг, олон хүн амьдрах зоригтой болж, дэлхий тэр аяараа өөрчлөгдсөнийг хардаг. Энэхүү аадар борооны дараа бүх зүйл Миний оюун санаанд байсан байдалдаа эргэн орж, дуулгаваргүй байхаа больдог. Төд удалгүй бүхий л газар нутаг инээд хөөрөөр дүүрч, газар сайгүй магтаалын уур амьсгал өрнөж, тэр чигтээ Миний алдраар дүүрнэ. Миний мэргэн ухаан газар дэлхий дээр, мөн сансар огторгуй даяар бий. Бүх зүйлийн дунд Миний мэргэн ухааны үр жимс байдаг, бүх хүний дунд Миний мэргэн ухааны охь бүтээлүүд элбэг арвин байдаг; бүх юм Миний хаанчлал дахь бүх зүйлтэй адил бөгөөд бүх хүн Миний бэлчээр дэх хонь мэт Миний тэнгэрүүдийн дор амралтад оршин суудаг. Би бүх хүний дээгүүр явж, хаа сайгүй харж байна. Ямар ч зүйл хуучин харагдахгүй, ямар ч хүн урьдынх шигээ байхгүй. Би сэнтийдээ амарч, бүхий л орчлон ертөнцийн дээр налан, бүрэн сэтгэл хангалуун байдаг, учир нь бүх зүйл ариун байдлаа буцаан авч, Би Сиондоо дахин нэгэнтээ амар тайван амьдарч, газар дээрх хүмүүс Миний удирдамж дор амар жимэр, сэтгэл хангалуун амьдарч чадна. Бүх хүн Миний гарт бүхнийг эрхэлж байгаа ба бүх хүн

урьдын оюун ухаан болон анхдагч дүр төрхөө эргүүлэн олж авсан; тэд тоосонд дарагдахаа болиод, харин Миний хаанчлалд, хаш мэт ариун агаад дор бүрнээ хүний зүрх сэтгэлд орших ариун нэгнийхтэй адил царайтай байдаг, учир нь Миний хаанчлал хүмүүсийн дунд байгуулагдсан билээ.

1992 оны 3 дугаар сарын 14

17-Р БҮЛЭГ

Миний айлдварууд аянга шиг нүргэлж, дөрвөн зүг найман зовхис, даян дэлхийг гэрэлтүүлдэг бөгөөд аянга цахилгаан дунд хүмүүс цохигдон унадаг. Аянга цахилгаан дунд нэг ч хүн бат зогссон нь үгүй; Миний гэрэл ирэхэд ихэнх хүн ухаан алдталаа айж, яах учраа олдоггүй. Зүүн зүгт бүүдгэр гэрэл сүүмэлзэн харагдаж эхлэхэд энэ өчүүхэн гэрэлд сэтгэл хөдөлсөн олон хүн өөрсдийн хий хоосон санаанаас даруй сэрнэ. Гэвч газар дэлхий дээр Миний гэрэл буух өдөр ирснийг хэн ч, хэзээ ч ухаараагүй. Гэрэл гэнэт ирэхэд хүмүүсийн дийлэнх олонх нь мэл гайхаж, цэл хөхрөн, зарим нь сониучирхсан харцаар гэрлийн хөдөлгөөн болон ирж буй зүг чигийг нь ажигладаг байхад зарим нь энэхүү гэрлийн эх сурвалжийг илүү тодорхой ойлгохын тулд гэрэлтэй нүүр тулахад бэлхэн зогсдог. Тэглээ ч гэсэн, өнөөдрийн гэрэл хэчнээн эрхэм нандин гэдгийг хэн нэгэн, хэзээ нэгэн цагт олж мэдсэн гэж үү? Энэхүү гэрлийн хосгүйг хэн нэгэн, хэзээ нэгэн цагт олж харсан гэж үү? Хүмүүсийн дийлэнх олонх нь ердөө л балмагддаг; гэрэлд нүд нь шархалж, шаварт хаягддаг. Энэ бүүдгэр гэрлийн дор эмх замбараагүй байдалд нэрвэгдэн тэсвэрлэхийн аргагүй өрөвдөлтэй харагдах газар дэлхийг сайтар ажвал дааж давшгүй уй гуниг төрдөг гэж хэлж болно. Гэрэл хамгийн хурц байх үед газар дэлхийн байдал хүн төрөлхтнийг Миний өмнө зогсоож чадахгүй гэдгийг хүн үүнээс ухан ойлгодог. Хүмүүс гэрлийн цацрагт оршдог; мөн бүх хүн гэрлийн авралд оршихын сацуу тэр гэрлийн учруулсан шархан дор оршдог: Гэрлийн үхлийн цохилт дор оршдоггүй хүн байна уу? Энэ гэрэлд шатахаас зайлсхийж чадах хүн байна уу? Газар дээрх бүх хүний сэтгэлийг хөдөлгөхийн тулд Би орчлон ертөнц даяар алхаж, Сүснийхээ үрийг Өөрийн гараар цацсан. Би тэнгэрийн хамгийн дээд өндөрлөгөөс дэлхийг тэр аяар нь харж, газар дээрх бүтээлүүдийн этгээд сонин, хачин дүр төрхийг ажигладаг. Далайн мандал газар хөдлөлтийн чичиргээнд нэрвэгдсэн мэт санагддаг: Тэнгисийн шувууд залгих загас хайн нааш цааш ниснэ. Харин далайн ёроол үүнийг огтхон ч үл мэднэ, гадаргуу дахь нөхцөл байдал үүнийг сэргээж огт үл чадна, учир нь далайн ёроол гурав дахь тэнгэр мэт амгалан байдаг: Тэнд том, жижиг амьтад хэзээ ч “хэл ам хийлгүй” эв эетэй зэрэгцэн оршдог. Тоо томшгүй хачин, жигтэй нөхцөл байдал дунд Намайг баярлуулах нь хүмүүст л хамгийн хэцүү байдаг. Хүнд Миний өгсөн байр суурь хэтэрхий өндөр, улмаар хүний санаархал

дэндүү их бөгөөд харцанд нь тодорхой хэмжээний дуулгаваргүй байдал үргэлж байдаг. Хүнийг сахилгажуулж, хүнийг шүүхэд минь уйгагүй хүчин чармайлт, сайхан сэтгэл асар их байсаар ирсэн ч хүн төрөлхтөн өчүүхэн төдий ч мэддэггүй. Би хэзээ ч, хэнд ч ширүүн хандаагүй; хүн төрөлхтнийг дуулгаваргүй байх үед тохиромжтой залруулга хийж, хүн төрөлхтнийг сул дорой байхад нь тохиромжтой тусламж санал болгосноос цаашгүй. Гэвч хүмүүс Надаас зайгаа барьж, түүнчлэн Миний эсрэг тэрслэхийн тулд Сатаны башир мэхийг ашиглах юм бол Би хүн төрөлхтнийг даруй устган, өмнө минь ур чадвараа гайхуулах боломж олгохгүй, ингэснээр тэд газар дэлхий дээр сүр үзүүлэн, нөхцөл байдлаараа сайрхан бусдыг дээрэлхэхээ болино.

Би газар дээр эрх мэдлээ хэрэгжүүлэн, Өөрийн ажлыг бүхэлд нь өрнүүлдэг. Миний ажилд багтдаг бүхэн газрын гадарга дээр тусгалаа олдог; газар дээрх хүн төрөлхтөн тэнгэр дэх Миний үйл хөдлөлийг ойлгож хэзээ ч чадаагүй, Миний Сүнсний үйл ажиллагааны хүрээ, тойрог замыг иж бүрнээр нь тунгаан бодож ч чадаагүй. Хүмүүсийн дийлэнх олонх нь сүнсний гаднах аар саар зүйлсийг л ухаараад, сүнсний бодит байр байдлыг ойлгох чадалгүй. Хүмүүст тавьдаг Миний шаардлага тэнгэрт байгаа тодорхойгүй Надаас, эсвэл газар дээр байгаа тодорхойлохын аргагүй Надаас гардаггүй; Би газар дээрх хүний биеийн хэмжээнд тохируулан зохих ёсны шаардлага тавьдаг. Би хэнийг ч хүнд байдалд оруулж байсан удаагүй, мөн Миний таалалд нийцэхийн тулд “цусаа шавх” гэж хэнээс ч, хэзээ ч шаардаж байгаагүй—Миний шаардлага ийм нөхцөлүүдээр л хязгаарлагддаг юм гэж үү? Газар дээрх тоо томшгүй олон бүтээлээс аль нь Миний амнаас гардаг үгийн зан чанарт захирагддаггүй вэ? Эдгээр бүтээлээс аль нь Миний өмнө ирээд Миний үг, Миний дүрэлзэх галд үнсэн товрог болдоггүй вэ? Эдгээр бүтээлийн аль нь бардан хөөрчхөөд Миний өмнө “сээхэлзэж” зүрхэлдэг вэ? Аль нь Миний өмнө бөхийдөггүй вэ? Би ердөө бүх бүтээлийг чимээгүй байлгадаг Бурхан юм гэж үү? Бүтээгдсэн үй олон зүйлийн дундаас Миний санаа зорилгыг хангах зүйлсийг Би сонгодог; үй олон хүн төрөлхтний дундаас зүрх сэтгэлийг минь анхаардаг хүмүүсийг Би сонгодог. Бүх одноос хамгийн шилдгийг нь сонгоод, тийнхүү Өөрийн хаанчлалд үл ялиг туяа нэмдэг. Би газар дэлхийгээр алхан, анхилуун үнэрээ хаа сайгүй ханхлуулж, Өөрийн дүрийг газар сайгүй үлдээдэг. Миний дуу хоолой энд тэндгүй цуурайтдаг. Газар газрын хүмүүс өчигдрийн сайхан зураглалыг санан мөрөөсдөг, учир нь бүх хүн өнгөрснийг санаж байна…

Миний царайг харахыг бүх хүн эгээрэн хүсдэг ч Намайг газар дээр биечлэн бууж ирэхэд бүгд ирсэнд минь дургүйцэж, Намайг тэнгэр дэх дайсан нь мэт үзэн, айсуй гэрлийг үлдэн хөөдөг. Хүн Надтай болгоомжилсон харцаар мэндчилж, үргэлж сонор сэрэмжтэй байж, Намайг өөрийнх нь талаар өөр төлөвлөгөөтэй байх вий гэхээс ихэд айдаг. Хүмүүс Намайг танил бус найз шигээ үздэг тул өөрсдийг нь ялгаварлалгүй хөнөөх санаа өвөрлөж байна гэж санадаг. Хүний нүдээр бол Би аминд халтай дайсан. Гай гамшиг дунд халуун сэтгэлийг минь мэдэрснийхээ дараа ч хүн Миний хайрыг мэддэггүй бөгөөд Надаас сэрэмжилж, эсэргүүцсээр байдаг.

Ийм нөхцөл байдалтай байгааг нь далимдуулан түүний эсрэг арга хэмжээ авахын оронд харин ч Би хүнийг халуун дотноор тэвэрч, амыг нь амттанаар дүүргэн, хэрэгтэй хоол ундыг ходоодонд нь хийдэг. Гэхдээ Миний уур хилэн уул усыг донсолгох үед хүний хулчгар зангаас үүдэн Би түүнд янз бүрийн тусламж цаашид үзүүлэхгүй. Энэ мөчид Миний уур хилэн бадарч, бүх амьд зүйлд гэмших боломж олгохоос татгалзаж, хүнд тавьсан бүх найдвараа орхиж, зохих залхаан цээрлүүлэлтийг түүнд онооно. Энэ үед далайн давлагаа уурсан догширч буй мэт, олон арван мянган уул нуран унаж буй мэтээр аянга цахилгаан цахилж, нүргэлнэ. Хүн тэрслүү зангийнхаа төлөө аянга цахилгаанд ниргүүлж, бусад бүтээл аянга цахилгааны ниргэлтэд арчигдах бөгөөд бүхий л ертөнц гэнэт эмх замбараагаа алдаж, бүтээлүүд амийн анхны амьсгалыг эргүүлэн олж авч чадахгүй. Тоймгүй олон хүн аянгын нүргээнээс зайлж чадахгүй; аянгын гялбаан дунд хүмүүс түргэн урсгалд түм бумаараа ойчин, уулнаас буух хүрхрээнд хамагдан арчигдана. Гэнэтхэн, хүний “хүрэх газар”-тай “хүмүүсийн” ертөнц нийлдэг. Далайн мандал дээр хүүр цогцос хөвнө. Хүн Миний Сүнсний мөн чанарын эсрэг нүгэл үйлдэж, тэрслүү зангаараа Надад халдсан тул Миний уур хилэнгээс үүдэн бүх хүн Надаас алс хол явдаг. Харин усгүй газруудад инээд хөөр, дуу хөгжим цалгин, Миний өгсөн амлалтыг бусад хүн эдэлсээр байдаг.

Бүх хүн дуугаа хураахад нүднийх нь өмнө Би гэрэл цацруулдаг. Тэгэхэд хүмүүсийн ухаан саруул болж, нүд нь гэрэлтээд чимээгүй байхыг хүсэхээ болино; тэгснээр сүнслэг мэдрэмж тэдний зүрх сэтгэлд даруй хурна. Энэ үед бүх хүн дахин амилдаг. Сэтгэлд бугшсан гомдлоо хаяад бүх хүн Миний өмнө ирж, Миний тунхагладаг үгээр дамжуулан амьд үлдэх дахин нэг боломжийг хүртсэн. Яагаад гэвэл, хүмүүс бүгд газрын гадарга дээр амьдрахыг хүсдэг. Тэгсэн атлаа тэдний дундаас хэн ер нь Миний төлөө амьдрах санаа зорилготой байсан бэ? Тэдний дундаас хэн ер нь Намайг зугаацуулах гайхамшигтай зүйлсийг өөрөөсөө олж илрүүлсэн бэ? Тэдний дундаас хэн ер нь Миний дур булаам үнэрийг олж үнэрлэсэн бэ? Бүх хүн бол бүдүүн хадуун, боловсроогүй зүйлс: Гаднаа гял цал харагдавч мөн чанартаа Намайг чин сэтгэлээсээ хайрладаггүй, учир нь хүний зүрх сэтгэлийн гүнд Миний ямар нэг элемент хэзээ ч байгаагүй. Хүн хэтэрхий дутуу дулимаг: Хүнийг Надтай харьцуулбал тэнгэр, газар шиг их ялгаа харагдана. Гэсэн ч Би хүний сул дорой, эмзэг цэг рүү довтолдоггүй, мөн дутагдлаас нь болж хүнээр доог тохуу хийдэггүй. Миний гар олон мянган жилийн турш газар дэлхий дээр ажилласаар ирсэн бөгөөд энэ бүх хугацаанд Миний нүд бүх хүнийг ажиглаж байлаа. Гэхдээ Би тоглоом шиг үзэн тоглох гэж ганц ч хүний амийг хээв нэг авсан удаагүй. Би хүний гаргасан хүчин чармайлтыг ажиглаж, төлсөн төлөөсийг нь ойлгодог. Өмнө минь зогсоо хүнийг Би гэнэдүүлэн гэсгээхийг хүсдэггүй, мөн түүнд таагүй зүйл өгөхийг ч хүсдэггүй. Харин ч энэ бүх хугацаанд Би гагцхүү хүнийг хангаж, хүнд өгсөн. Иймээс бүх хүн гагцхүү Миний нигүүлсэл, Миний гараас ирдэг өгөөмөр шанг л эдэлдэг. Би газар дээр байгаа учраас хүн өлсөхийн зовлонг хэзээ ч амсах шаардлагагүй

байсан. Харин ч Би эдэлж болох зүйлсийг нь Өөрийн гараас хүнд хүртээж, хүн төрөлхтнийг Өөрийн ерөөлд амьдруулдаг. Бүх хүн төрөлхтөн Миний гэсгээлт дор амьдардаг бус уу? Уулсын гүнд элбэг дэлбэг зүйлс байдаг, мөн ус мөрөнд эдлэх зүйлс арвин байдгийн адил өнөөдөр Миний үгэн дотор амьдарч буй хүмүүст өөрсдийнх нь таашааж, амтлах хоол бүр ч их байдаг бус уу? Би газар дээр байж, хүн төрөлхтөн газар дээр Миний ерөөлийг эдэлдэг. Би газар дэлхийг орхин явж, Миний ажил ч бас дуусах үед хүн төрөлхтөн өөрсдийн сул дорой байдлаас болж Надаас ямар ч хүлцлийг хүлээн авахаа болино.

1992 оны 3 дугаар сарын 16

18-Р БҮЛЭГ

Аянгын гялбаанд амьтан бүр үнэн төрхөө харуулдаг. Тиймээс Миний гэрлээр гэрэлтүүлэгдээд хүн ч бас нэгэнтээ эзэмшиж байсан анхны ариун байдлаа сэргээсэн. Өө, завхарсан хуучин дэлхий ертөнц! Эцэстээ бохир ус руу нуран унаж, газрын гадаргаас доош живж, лаг шавар болон уусжээ! Өө, Миний бүтээсэн бүх хүн төрөлхтөн! Эцэстээ тэд гэрэлд дахин амь орж, оршин тогтнолын үндсийг олж, шавар шавхай дотор тэмцэлдэхээ больжээ! Өө, Миний гарт байдаг тоо томшгүй олон бүтээл! Тэд Миний үгээр шинэчлэгдэхгүй байж яахан чадах билээ? Гэрэлд тэд чиг үүргээ гүйцэтгэхгүй байж яахан чадах билээ? Газар дэлхий нам гүм, дуу чимээгүй байхаа больж, тэнгэр зэлүүд, гунигтай байхаа больсон. Тэнгэр, газар оргүй хоосноор тусгаарлагдахаа больж, дахин хэзээ ч салахгүйгээр нэг болон нэгдлээ. Энэхүү баярт учрал тохиох хөөр баяртай мөчид Миний зөвт, ариун байдал орчлон ертөнц даяар түгсэн ба бүх хүн төрөлхтөн тэдгээрийг тасралтгүй шагшин магтдаг. Тэнгэрийн хотууд баярлан инээж, газрын хаанчлалууд баярлан бүжиглэж байна. Энэ мөчид баярлахгүй хэн байх билээ, мөн уйлахгүй хэн байх билээ? Газар анхны байдлаараа тэнгэрт харьяалагддаг ба тэнгэр газартай нэгдсэн байдаг. Хүн бол тэнгэр, газрыг нэгтгэх холбоос бөгөөд хүн ариун болсны ачаар, хүн шинэчлэгдсэний ачаар тэнгэр нь газраас нуугдахаа больж, газар нь тэнгэрийн зүг анир чимээгүй байхаа больсон байна. Хүн төрөлхтний царайд жаргалтай инээмсэглэл тодорч, тэдний зүрх сэтгэлд хэмжээлшгүй жаргал нуугдаж байдаг. Хүн хүнтэйгээ хэрэлддэггүй, бие биетэйгээ ч зодолддоггүй. Миний гэрэлд бусадтай эв найртай амьдардаггүй хэн байна вэ? Миний өдөр Миний нэрийг гутаан доромжлох хэн байна вэ? Бүх хүн хүндэтгэлтэй харцаар Намайг харж, зүрх сэтгэлдээ Намайг дуудаж нууцхан хашхирдаг. Би хүн төрөлхтний үйлдэл бүрийг шинжилсэн: Цэвэрлэгдсэн хүмүүсийн дунд Надад дуулгаваргүй нэг ч хүн үгүй, Намайг шүүдэг нэг ч хүн үгүй. Бүх хүн төрөлхтөнд Миний зан чанар тархаж байдаг. Хүн бүр Намайг мэддэг болж, Надтай улам ойртож, Намайг биширч байна. Би хүний сүнсэнд бат

зогсож, хүний нүдээр хамгийн өндөрт өргөмжлөгдөж, хүний судсан дахь цусаар дамжин урсдаг. Хүний зүрх сэтгэл дэх баяр хөөр газрын гадаргуу дээрх бүх газар нутгийг дүүргэж, агаар цэвэр цэнгэг байж, өтгөн манан газрыг бүрхэхээ больж, нар цог жавхаатайгаар гялбана.

Миний хаанчлалыг харвал Би бүгдийн дээр Хаан сууж, бүгдийг захирч байна. Бүтээлийн эхнээс өнөөг хүртэл Миний хөвгүүд Надаар удирдуулж, амьдралын маш олон бэрхшээлийг, дэлхий ертөнцийн шударга бус үйл явдлыг, дэлхий ертөнцийн маш олон аз, эзийг туулаад одоо Миний гэрэлд амьдардаг. Өчигдрийн шударга бус явдлын төлөө уйлдаггүй хэн байх билээ? Өнөөдрийг хүртэл туулсан зовлон бэрхшээлд нулимс урсгадаггүй хэн байх билээ? Дахин хэлэхэд, Надад өөрсдийгөө зориулахын тулд энэ завшааныг ашигладаггүй хэн байх билээ? Зүрх сэтгэлд нь хурж буй хүсэл тэмүүллийг илэрхийлэх боломжийг алдахыг хэн хүсэх билээ? Энэ мөчид юу туулснаа илэрхийлдэггүй хэн байх билээ? Энэ үед бүх хүн өөрсдийн хамгийн сайн хэсгийг Надад зориулж байна. Хэчнээн хүн өнгөрсөн үеийн мунхаг тэнэглэлдээ харамсан шаналж, хэчнээн хүн өчигдрийн эрэл хайгуулынхаа төлөө өөрсдийгөө үзэн яддаг билээ! Хүмүүс бүгд өөрсдийгөө мэдэж авсан, бүгдээрээ Сатаны үйл хэрэг болон Миний гайхалтай байдлыг харсан бөгөөд одоо зүрх сэтгэл дотор нь Надад зориулсан орон зай бий болсон. Би хүмүүсийн дунд зэвүүцэл юм уу гололттой дахин тулгарахгүй, учир нь Миний агуу ажил аль хэдийн гүйцэлдсэн бөгөөд дахин саад тохиолдохгүй. Өнөөдөр Миний хаанчлалын хөвгүүдийн дунд, өөрсдийгөө бодож үзээгүй хүн байна уу? Миний ажлын арга барилд илүү их анхаарал тавьдаггүй хүн байна уу? Миний төлөө чин сэтгэлээсээ өөрийгөө өргөсөн хүн байна уу? Та нарын зүрх сэтгэл доторх хольц багассан уу? Эсвэл ихэссэн үү? Хэрвээ та нарын зүрх сэтгэл дэх хольцтой зүйлс их ч болоогүй, бага ч болоогүй бол та нар шиг ийм хүмүүсийг Би ямар ч эргэлзээгүйгээр хаяна. Миний хүсдэг зүйл бол Миний эсрэг тэрсэлдэг бузар чөтгөрүүд биш, харин Миний зүрх сэтгэлийн дагуу байдаг ариун хүмүүс билээ. Хүн төрөлхтөнд тавьдаг Миний шаардлага өндөр биш хэдий ч хүний зүрх сэтгэлийн дотоод ертөнц маш адармаатай учраас хүн төрөлхтөн Миний хүсэлтэй амархан нийцэж, Миний санаа зорилгыг тэр даруй биелүүлж чаддаггүй. Хүмүүсийн дийлэнх нь эцсийн ялалтын титэм олж авах найдлага өвөрлөн нууцаар чармайн зүтгэж байна. Хүмүүсийн ихэнх нь хоромхон зуур ч хойргошиж үл зүрхлэн хамаг чадлаараа махран шамдаж, хоёр дахь удаагаа Сатанд олзлогдохоос ихэд айж байна. Тэд Миний эсрэг гомдол өвөрлөж зүрхлэхээ болиод, харин Миний өмнө байнга үнэнч байдлаа харуулж байдаг. Би маш олон хүний чин сэтгэлээсээ хэлсэн үгийг сонсож, зовлон зүдүүр дундах шаналгаат туршлагынхаа талаар маш олон хүний ярихыг сонссон; хүнд бэрх нөхцөлд үнэнч байдлаа Надад өргөн барьдаг маш олон хүнийг Би харсан ба бартаат замаар алхангаа гарах гарц хайж байгаа маш олон хүнийг ажигласан. Ийм нөхцөл байдалд тэд хэзээ ч гомдоллоогүй; гэрэл олж чадахгүй байх үедээ ч гэсэн, бага зэрэг гонсойсон ч ганц ч удаа гомдоллоогүй. Гэхдээ Би бас маш олон хүн зүрх

сэтгэлийнхээ гүнээс хараал урсган, Тэнгэрийг зүхэж, газрыг буруутгаж байхыг сонссон, түүнчлэн гай зовлон дайрахад маш олон хүн өөрсдийгөө гаргуунд нь гаргаж, хог новш адил хогийн саванд хаяж, бохир заваан, хир буртгаар хучигдахыг ч харсан. Байр суурь нь өөрчлөгдсөнөөс үүдэн нэр нүүр нь өөрчлөгдөж, улмаар хүмүүсийн хоорондох харилцаанд нь өөрчлөлт орсноор маш олон хүн нэг нэгэнтэйгээ хэрэлдэж байхыг Би сонссон, тэгээд найзууд найзлахаа болиод дайсан болж, бие биеэ үг хэлээр дайрч байсан. Хүмүүсийн дийлэнх олонх нь Миний үгийг пулемётны сум адил хэрэглэж, хүний ертөнц хаа сайгүй орилоон шуугианаар дүүрч, нам гүмийг нураах хүртэл бусдыг гэнэдүүлэн хайр найргүй гал нээдэг. Аз болоход энэ өдөр одоо ирсэн; тэгээгүй бол энэхүү пулемётны өршөөлгүй галд хэр олон хүн үхэж үрэгдэх байсныг хэн мэдэх билээ.

Надаас гарсан үгийг дагаад, бүх хүн төрөлхтний нөхцөл байдалтай хөл нийлүүлэн Миний хаанчлал алхам алхмаар газар дээр буудаг. Хүн цаашид түгшүүртэй бодол өвөрлөж, бусад хүмүүсийг “харгалзан үзэж”, эсвэл тэдний талаар “бодохоо” болино. Иймээс, газар дээрх хэрүүл маргаан үгүй болж, Миний үгийг дагаад орчин үеийн элдэв янзын “зэвсэг” ч бас хураагддаг. Хүн хүнтэйгээ дахин эв найртай болж, зүрх сэтгэл нь эв зохицлын сэтгэлээр дахин нэгэнтээ гэрэлтэж, хэн ч нууц дайралтын эсрэг сэрэмжлэхээ болино. Бүх хүн хэвийн байдалдаа эргэн орж, шинэ амьдрал эхлүүлсэн. Шинэ орчинд амьдарч байхдаа үлэмж олон хүн эргэн тойрноо хараад цоо шинэ ертөнцөд ирсэн мэт санагддаг, тийм учраас тэд одоогийн орчиндоо нэн даруй дасан зохицоод, зөв замд даруй орж чаддаггүй. Иймээс хүн төрөлхтний тухайд гэвэл, “санаа байвч сачий нь хүрэхгүй” байдаг. Хэдийгээр Би Өөрөө хүнтэй адил зовлон бэрхшээлийн гашууныг амсаагүй ч хүний хангалтгүй байдлын талаар мэдэж болох бүхнийг мэддэг. Би хүний хэрэгцээг андахгүй мэддэг бөгөөд түүний сул дорой байдлын талаарх Миний ойлголт бүрэн дүүрэн юм. Ийм учраас Би хүний дутагдлаар тоглоом тохуу хийдэггүй; Би хүн бүрийг зөв замд оруулахын тулд зөв шударга бус байдлаас нь хамаарч, тохиромжтой “боловсрол” олгодог, ингэснээр хүн төрөлхтөн тэнэмэл өнчин байхаа болиод, гэр оронтой нялх хүүхдүүд болно. Гэхдээ Миний үйлдлүүд зарчимд захирагддаг. Хэрвээ хүмүүс Миний дотор байгаа аз жаргалыг эдлэх хүсэлгүй бол Би тэдний хүслээр болгохоос өөр юм хийж чадахгүй бөгөөд тэднийг ёроолгүй гүн нүх рүү илгээнэ. Энэ мөчид хэн ч зүрх сэтгэлдээ гомдол өвөрлөх ёсгүй, харин бүгд Миний хийсэн зохицуулалтуудаас Миний зөвт байдлыг харж чаддаг байх ёстой. Би Намайг хайрла гэж хүн төрөлхтнийг албадахгүй, мөн Намайг хайрласных нь төлөө ямар ч хүнийг цохихгүй. Миний дотор бүрэн эрх чөлөө, бүрэн чөлөөлөлт байдаг. Хэдийгээр хүний хувь заяа Миний гарт байдаг ч Би хүнд чөлөөт хүсэл өгсөн бөгөөд энэ нь Миний хяналтад байдаггүй. Ийм маягаар хүмүүс Миний захиргааны зарлигаас болж өөрсдөдөө төвөг удахгүй, харин ч Миний уужим сэтгэлд найдан “сул чөлөөтэй” болно. Тиймээс олон хүн Надад хязгаарлагдан баригдахын оронд чөлөөлөгдөх явцдаа өөрсдийн гарах гарцыг эрж хайдаг.

Би хүн төрөлхтөнд үргэлж чөлөөтэй хандаж байсан ба шийдвэрлэх аргагүй асуудлыг хүмүүст хэзээ ч өгч байгаагүй, ганц ч хүнд бэрхшээл учруулж байгаагүй. Тийм биш гэж үү? Хэдийгээр асар олон хүн Намайг хайрладаггүй ч ийм хандлагаас нь болж Би огт бухимддаггүй, харин ч тэдэнд эрх чөлөө өгч, зовлон зүдүүрийн далайд чөлөөтэй сэлэхийг нь ч зөвшөөрөх хэмжээний их эрх чөлөө олгосон. Учир нь, хүн бол үнэ хүндгүй сав юм; хэдийгээр тэр Миний гарт байгаа ерөөлийг хардаг ч үүнийг эдэлье гэж огт сонирхдоггүй, харин оронд нь Сатаны гарт буй гай гамшгаас түүн авч, улмаар Сатаны “тэжээл” нь болон залгиулаад өөрийгөө мөхөөдөг. Мэдээж, Миний гэрлийг нүдээр үзсэн зарим хүн бий, иймээс тэд өнөө үеийн манан будан дунд амьдарч байгаа ч гэсэн энэ манангаас болоод гэрэлд итгэх итгэлээ алдаагүй, харин явж буй зам нь саад тотгороор бүрхэгдсэн ч манан дундуур тэмтчин, эрж хайсаар байдаг. Хүн Миний эсрэг тэрслэхэд Би уур хилэнгээ түүний дээр буулгадаг тул хүн дуулгаваргүй байдлаасаа болоод мөхөх болно. Надад дуулгавартай байхад нь Би түүнээс нуугдсан хэвээр байдаг ба ийм маягаар Намайг аргалахаар хичээдэг биш, харин Намайг баярлуулж чадах хайрыг түүний зүрх сэтгэлийн гүнд төрүүлдэг. Хүний жинхэнэ итгэлийг олж авахын тулд Би Намайг гэсэн хүний эрэл хайгуулд маш олон удаа нүдээ аньж, чимээгүй өнгөрсөн. Гэвч Намайг үг хэлэхгүй байх үед хүний итгэл агшин зуурт өөрчлөгдөж, Би түүний “хуурамч барааг” л хардаг, учир нь хүн Намайг хэзээ ч чин сэтгэлээсээ хайрлаж байгаагүй. Намайг Өөрийгөө харуулах үед л хүмүүс бүгд асар их “итгэлтэй” дүр үзүүлдэг; гэвч Намайг нууц газартаа нуугдаж байхад тэд Надад халдахаас айсан мэт сул дорой, хулчгар болдог; зарим нь бүр Миний нүүрийг харж чадалгүй, Намайг “гүн гүнзгий боловсруулж”, улмаар Миний оршин тогтнолын үнэнийг үгүйсгэж байдаг. Маш олон хүн ийм байдалтай үлддэг; маш олон хүн ийм бодол санаатай байдаг. Бүх хүн өөрсдийнхөө муу муухайг далдлах сонирхолтой байдгаас цаашгүй. Үүнээс болж тэд хангалтгүй байдалдаа анхаарал татах дургүй байдаг бөгөөд шүд зуун, нүүрээ нууснаар л Миний үгийн үнэнийг хүлээн зөвшөөрдөг.

1992 оны 3 дугаар сарын 17

19-Р БҮЛЭГ

Миний үгийг оршин тогтнолынхоо үндэс болгон авч үзэх нь хүний үүрэг юм. Хүн Миний үгийн хэсэг тус бүрд өөрийн хувийг бий болгох ёстой; ингэхгүй бол сүйрлээ хайж, жигшил зэвүүцэл дуудаж байгаа хэрэг. Хүн Намайг мэддэггүй, үүнээсээ болоод солилцоо хийх гэж амиа Надад авчрахын оронд зүгээр л гар дахь хог новшоо Миний өмнө үзүүлэхээр оролдож, үүгээрээ Надад сэтгэл ханамж өгөхөөр хичээдэг. Гэхдээ Би байгаа байдалд сэтгэл огт ханалгүй, хүнд шаардлага тавьсаар байдаг. Би хүний хувь нэмрийг хайрлаж, шаардлагыг нь үзэн яддаг. Бүх хүн

шуналаар дүүрэн зүрх сэтгэлтэй; хүний зүрх сэтгэл диаволд олзлогдсон мэт байдаг бөгөөд хэн ч үүнээс чөлөөлөгдөж, зүрх сэтгэлээ Надад өргөн барих чадваргүй байдаг. Намайг үг хэлэх үед хүмүүс Миний дуу хоолойг анхаарлаа төвлөрүүлэн сонсдог; харин Намайг үг хэлэхээ болиход өөрсдийн “ажил хэргийг” дахин эхлүүлж, Миний үгийг ажил хэргийнх нь нэмэлт зүйл мэтээр үзэж, огт хайхрахаа больдог. Би хүнд хэзээ ч хайнга хандаж байгаагүй, харин ч тэвчээртэй, хүлээцтэй хандсаар ирсэн. Иймээс уучлалаас минь үүдэн хүмүүс бүгд өөрсдийгөө хэт өндрөөр үнэлж, өөрийгөө танин мэдэж, өөрийгөө эргэцүүлэх чадваргүй болсон; тэд ердөө хүлээцтэй байдлыг минь далимдуулан Намайг хуурдаг. Тэдний дундаас нэг нь ч Намайг чин сэтгэлээсээ анхааран халамжилдаггүй, нэг нь ч Намайг зүрх сэтгэлийнх нь эрхэм зүйл хэмээн нандигнадаггүй; илүүчлэх цаг завтай үедээ л тэд Надад хааш яаш анхаарал хандуулдаг. Хүнд зарцуулсан Миний хичээл чармайлт хэдийнээ хэмжээлшгүй их. Би урьд өмнө нь байгаагүй ажлыг хүнд хийснээс гадна, Надад юу байгаа, Би юу болохоос хүн мэдлэг олж авч, өөрчлөгдөх байх гэсэндээ Би түүнд нэмэлт ачаа өгсөн юм. Би хүмүүсээс “хэрэглэгч” төдий бай гэж шаарддаггүй, харин Сатанд ялагдал учруулах “үйлдвэрлэгч” бай гэж шаарддаг. Би хүнээс ямар нэг зүйлийг хий гэж шаардахгүй боловч Миний хүнд тавих шаардлагад стандарт гэж бий, учир нь Миний хийдэг зүйлд зорилго бий, түүнчлэн Миний үйлдэлд үндэслэл бий: Би хүний төсөөлдөгчлөн замбараагүй наргиж нааддаггүй, эсвэл тэнгэр, газар болон бүх зүйлийг дур зоргоороо бүтээдэггүй. Миний ажлаас хүн ямар нэгэн зүйлийг харж, олж авч чаддаг байх ёстой. Тэрээр залуу халуун насаа үрэн таран хийж, өөрийн амийг тоос шороо хамаагүй цуглуулдаг хувцас шиг авч үзэх ёсгүй; харин ч өөрийгөө чанд хамгаалж, Миний төлөө Сатан руу эргэж буцахгүй байж, Миний төлөө Сатаны эсрэг дайралт хийдэг болох хүртлээ Миний баялгаас авч эдлэх хэрэгтэй. Хүнээс Миний шаарддаг зүйл ийм энгийн биш гэж үү?

Зүүн зүгт бүдэгхэн сүүмэлзэх гэрэл харагдаж эхлэх үед, түүнээс болж орчлон ертөнц дээрх бүх хүн Зүүн зүг дэх гэрэлд бага зэрэг анхаарал хандуулдаг. Хүн нойронд умбахаа болиод зүүний гэрлийн эх сурвалжийг ажиглахаар явах боловч хүний хүч чадлын хязгаарын улмаас гэрэл гарч байгаа газрыг хэн ч харж чаддаггүй. Орчлон ертөнц дээрх бүхэн бүрэн гэрэлтүүлэгдэхэд хүн зүүд нойрноос сэрж, Миний өдөр өөрсөд дээр нь аажмаар ирж буйг дөнгөж л ухаарна. Гэрэл ирсэн учир бүх хүн баярлан хөгжилддөг ба бөх нойрсохоо больж, ухаанаа алдахаа больдог. Миний гэрлийн туяан дор бүх хүний ухаан, хараа цэлмэж, амьдрахын баяр баясгаланг гэнэт мэдэрдэг. Манангийн халхавчин дор Би дэлхий ертөнцийг хардаг. Амьтад бүгд амарч байдаг; бүдэгхэн сүүмэлзэх гэрэл гарснаас болж бүх зүйл шинэ амьдрал ойртож байгааг ухамсарладаг. Энэ шалтгааны улмаас амьтад ч бүгд үүрнээсээ мөлхөн гарч, хоол хүнс хайдаг. Мэдээж ургамал ч гэсэн ялгаагүй бөгөөд гэрлийн туяанд ногоон навчис нь гялтганан гялалзаж, Намайг газар дээр байх хугацаанд өөрсдийн хувийг Надад зориулахаар хүлээдэг. Бүх хүн гэрлийг ирээсэй гэж хүсдэг атлаа халхлах юмгүй нүв нүцгэн учраас гэрэл ирэхээс бүгд айж, муу

муухайгаа далдлах юмгүй болох вий хэмээн түгшдэг. Айсуй гэрлээс болж хэчнээн хүн балмагдаж, гэрэл гарч ирснээс болж хэчнээн хүн цочирдсон байдалтай байна вэ? Гэрлийг хараад хэдэн хүн энгүй харууслаар дүүрч, бохир заваан байдлаа үзэн ядсан боловч гүйцэлдсэн баримт нэгэнтээ өөрчлөгдөшгүй болж, зөвхөн ял тулгахыг минь хүлээхээс өөр аргагүй байдаг билээ. Харанхуйд зовлонгоор цэвэршүүлэгдсэн хэчнээн хүн гэрлийг үзээд гүн гүнзгий утга учрыг нь гэнэт мэдэрч, үүнээс хойш гэрлийг энгэртээ чанга тэврэн, дахин алдахаас ихэд айдаг вэ? Хэчнээн хүн гэрэл гэнэт гарч ирснээс болж тогтворгүй болохын оронд зүгээр л гар дахь ажлаа хийж, олон жил сохор явсан учраас, гэрэл ирснийг анзаарах ч үгүй, үүнд баярлах ч үгүй байдаг билээ. Хүмүүсийн зүрх сэтгэлд Би агуу дээд ч биш, эгэл дорд ч биш байдаг. Хүмүүсийн хувьд Миний оршдог эсэх нь ямар ч ялгаагүй бөгөөд Намайг оршин байгаагүй ч хүний амьдрал илүү ганцаардмал болохгүй, Намайг оршин байсан ч илүү тааламжтай болохгүй мэт байдаг. Хүмүүс Намайг нандигнадаггүй учраас тэдэнд Миний өгч чадах таашаан эдлэх зүйл цөөхөн. Гэхдээ хүн Надад өчүүхэн төдий л хайр хүндлэл өгмөгц Би ч бас хүнд хандах хандлагадаа өөрчлөлт хийдэг. Иймээс хүн энэ хуулийг ухаарах үедээ л өөрсдийгөө Надад зориулж, гартаа барьж байгаа зүйлсийг минь хүсэх хувьтай болно. Намайг гэх хүний хайр гагцхүү өөрийнх нь сонирхлоор хязгаарлагдана гэж үү? Надад итгэх итгэл нь гагцхүү Миний өгдөг зүйлээр хязгаарлагдана гэж үү? Гэрлийг минь харахгүй л бол хүн итгэлээрээ Намайг үнэхээр хайрлаж чадахгүй юм гэж үү? Хүний эрч хүч үнэхээр өнөөдрийн нөхцөл байдлаар хязгаарлагддаг юм гэж үү? Намайг хайрлахын тулд хүнд эр зориг хэрэгтэй юм гэж үү?

Миний оршин тогтнолоос үүдэн бүх зүйл оршин суугаа газартаа дуулгавартай захирагддаг бөгөөд Миний сахилгажуулалт байхгүй байхад эрээ цээргүй авирладаггүй. Тиймээс, уулс хуурай газар дээрх улс үндэстнүүдийн хооронд хил хязгаар болж, ус хуурай газруудын хооронд хүмүүсийг тусгаарлах хаалт болж, агаар нь газар дэлхий дээрх орон зайд хүнээс хүн рүү урсдаг зүйл болдог. Хүн л Миний хүслийн шаардлагыг үнэхээр дуулгавартай дагах чадваргүй; ийм учраас бүх бүтээл дундаас хүн л дуулгаваргүй зүйлийн ангилалд ордог гэж Би хэлдэг. Хүн хэзээ ч Надад үнэхээр захирагдаж байгаагүй, ийм учраас Би хүнийг үргэлж чанд захиралт дор байлгасаар ирсэн. Хүний дунд Миний алдар суу үнэхээр бүхий л орчлон даяар түгэх юм бол Би бүх алдар суугаа хүнд харуулах болно. Хүн бузар булай байж, Миний алдар сууг харахад тохирохгүй учраас хэдэн мянган жилийн турш Би хэзээ ч ил харуулаагүй, харин нуугдмал хэвээр үлдсэн юм; ийм учраас Миний алдар суу хүнд хэзээ ч илчлэгдээгүй бөгөөд хүн нүглийн гүн ангалд үргэлж живээтэй байсан билээ. Би хүний зөв шударга бус байдлыг уучилсан боловч хүмүүс өөрсдийгөө хамгаалахыг мэддэггүй, харин ч өөрсдийгөө үргэлж нүгэлд өртөмхий байлгаж, өөрсдийг нь хохироох боломжийг нүгэлд олгодог. Энэ чинь, хүнд өөрийгөө гэх хүндлэл, хайр дутсан хэрэг бус уу? Хүмүүсийн дунд үнэхээр хайрлаж чаддаг хүн бий юу? Хүний үнэнч зан хэдэн лан жинтэй вэ? Хүний жинхэнэ байдал гэгчид

хуурмаг хольц холилдоогүй гэж үү? Хүний үнэнч зан бүхэлдээ холион бантангаас бүрддэг бус уу? Миний шаарддаг зүйл бол хүний хоёргүй хайр юм. Хүмүүс Намайг мэддэггүй бөгөөд Намайг мэдэхээр эрж хайдаг ч жинхэнэ, чин үнэнч сэтгэлээ Надад өгдөггүй. Өгөхийг хүсэхгүй байгаа зүйлийг нь Би хүмүүсээс хүчээр шаарддаггүй. Хүн Надад үнэнч байдлаа өгвөл Би огтхон ч эрээлэлгүй хүлээн авна. Харин Надад итгэхгүй, мөн өөрийнхөө өчүүхэн хэсгийг ч Надад өргөн барихаас татгалзах юм бол Би ингэлээ гэж илүү их уцаарлахын оронд хүнийг зүгээр л өөр нэг аргаар шийдвэрлэж, тохиромжтой хүрэх газарыг нь зохицуулна. Тэнгэрт аянга нүргэлэн хүмүүсийг ниргэн унагана; өндөр уулс нуран унахдаа тэднийг булшилна; зэрлэг араатнууд өлссөндөө тэднийг залгина; далай тэнгис давлагаалах үедээ толгой дээгүүр нь нөмрөн авна. Хүмүүс хоорондоо хөнөөн тэмцэлдэх үедээ өөрсдөөс нь урган гардаг гамшгаас болж бүгд сүйрлээ эрнэ.

Хаанчлал хүмүүсийн дунд өргөжиж, хүмүүсийн дунд бүрэлдэж, хүмүүсийн дунд өндийн босож байна; Миний хаанчлалыг устгаж чадах ямар ч хүч байхгүй. Өнөөдрийн хаанчлалд байгаа ардуудаас хэн чинь хүмүүсийн дундах нэг гишүүн биш вэ? Та нараас хэн чинь хүний нөхцөл байдлын гадна оршдог вэ? Миний шинэ эхлэх цэг олон түмэнд зарлагдах үед хүмүүс хариуд нь яах вэ? Хүний ертөнцийн байдлыг та нар нүдээрээ харсан; та нар энэ дэлхий ертөнцөд үүрд амьдрах найдлага өвөрлөдөггүй биз дээ? Би одоо Өөрийнхөө ардуудын дунд алхаж, дунд нь амьдарч байна. Өнөөдөр Намайг жинхэнээсээ хайрладаг хүмүүс ерөөлтэй ээ; Надад захирагддаг хүмүүс ерөөлтэй ээ, тэд Миний хаанчлалд үлдэх нь лавтай. Намайг мэддэг хүмүүс ерөөлтэй ээ, тэд Миний хаанчлалд эрх мэдэл эзэмших нь лавтай. Намайг эрж хайдаг хүмүүс ерөөлтэй ээ, тэд Сатаны хүлээсээс зугтаж, Надаас ерөөл эдлэх нь дамжиггүй. Өөрсдийгөө хаяж чаддаг хүмүүс ерөөлтэй ээ, тэд гарцаагүй Миний эзэмшилд орж, Миний хаанчлалын баялгийг өвлөнө. Миний төлөө ийш тийш гүйдэг хүмүүсийг Би санаж, Миний төлөө зарлагаддаг хүмүүсийг баяртайгаар хүлээн авна, мөн Надад тахил өргөдөг хүмүүст Би таашаан эдлэх зүйл өгнө. Миний үгийг таашаан эдэлдэг хүмүүсийг Би ерөөнө; тэд Миний хаанчлалын гол нурууг тулах багана байх нь гарцаагүй, тэд Миний гэрт хосгүй их баялагтай байх нь лавтай, хэн ч тэдэнтэй эн зэрэгцэж чадахгүй. Өөрсдөд чинь өгсөн ерөөлийг та нар ер нь хүлээн авсан уу? Та нарт өгсөн амлалтыг ер нь эрж хайсан уу? Та нар Миний гэрлийн удирдамж дор харанхуйн хүчний дарлалаас гарцаагүй ангижирч, харанхуйн дунд өөрсдийг чинь замчлах гэрлийг алдахгүй нь лавтай. Та нар бүх бүтээлийн эзэн байх нь лавтай. Та нар Сатаны өмнө ялагч байх нь гарцаагүй. Агуу улаан лууны хаанчлал нуран унахад та нар Миний ялалтад гэрчлэл хийхээр үй олон хүн дунд зогсох нь гарцаагүй. Синимийн нутагт та нар бат, тууштай зогсох нь маргаангүй. Туулсан зовлонгоороо дамжуулан та нар Миний ерөөлийг өвлөж, бүхий л орчлон ертөнц даяар Миний алдрыг цацруулах нь дамжиггүй.

1992 оны 3 дугаар сарын 19

20-Р БҮЛЭГ

Миний гэрийн баялаг тоо томшгүй, хэмжээлшгүй атал тэдгээрийг эдлэхийн тулд хүн хэзээ ч Над дээр ирээгүй. Хүн тэдгээрийг өөрөө ганцаараа эдлэх чадваргүй, мөн хүчин чармайлтаа ашиглан өөрийгөө хамгаалах ч чадваргүй; харин ч үргэлж бусдад итгэж найддаг. Миний хардаг бүх хүнээс нэг нь ч Намайг хэзээ ч өөрийн ухамсраар, шууд эрж хайгаагүй. Тэд бүгд бусдын шахалтаар, олонхыг дагаж Миний өмнө ирдэг бөгөөд тэд өөрсдийн амьдралыг баялаг болгохын тулд төлөөс төлөх юм уу цаг хугацаа зарцуулах хүсэлгүй байдаг. Тиймээс хүмүүсийн дундаас хэн ч, хэзээ ч бодит байдалд амьдраагүй бөгөөд бүх хүн утга учиргүй амьдралаар амьдардаг. Хүний урт хугацааны туршид тогтсон арга зам, ёс заншлын улмаас бүх хүний биед газрын хөрсний үнэр нэвчсэн. Үр дүнд нь хүн хөшүүн болж, дэлхий ертөнцийн хоосролыг мэдрэхээ болиод энэхүү хүйтэн цэвдэг дэлхийд өөрийгөө зугаацуулах ажил хийн завгүй байдаг. Хүний амьдралд өчүүхэн төдий ч халуун дулаан байдал байдаггүй бөгөөд хүн чанарын ямар ч ул мөр, гэрэл гэгээ байдаггүй—гэсэн ч тэр үргэлж өөрийгөө өөгшүүлж, юунд ч хүрсэн юмгүй яаран тэвдэж, насан туршдаа ямар ч үнэ цэнгүй амьдардаг. Насан эцэслэх өдөр нь нүд ирмэхийн зуур ойртож, хүн гашуун үхлээр нас бардаг. Энэ дэлхий дээр тэр хэзээ ч, юу ч биелүүлээгүй, эсвэл юу ч олж аваагүй—тэрээр яаран ирж, яаран оддог. Миний нүдээр харвал, тэдний хэн нь ч юу ч авчраагүй, эсвэл юу ч авч одоогүй, иймээс хүнд дэлхий ертөнц шударга бус санагддаг. Гэхдээ хэн ч яаран одохыг хүсдэггүй. Миний амлалт тэнгэрээс хүмүүсийн дунд гэнэт ирж, замаа алдсан үед нь мөнх амийн замыг дахин нэг харуулах өдрийг тэд зүгээр л хүлээдэг. Тиймээс өөрт нь өгсөн амлалтаа үнэхээр биелүүлсэн эсэхийг минь харахын тулд хүн Миний үйл хэрэг, үйлдэл бүрийг ширтдэг. Гай зовлон дунд, туйлын их шаналал дунд байхдаа, эсвэл шалгалтад орж, унахын даваан дээр байхдаа хүн бэрхшээлээсээ хурдхан зугтаж, өөр хүслэнт газар луу очих гэсэндээ өөрийнхөө төрсөн өдрийг хараан зүхдэг. Гэхдээ шалгалт өнгөрөхөд хүн баяр хөөрөөр бялхдаг. Тэрээр газар дэлхий дээр төрсөн өдрөө тэмдэглэж, төрсөн өдрийг нь ерөөгөөч гэж Надаас гуйдаг; энэ үед хүн өнгөрсөн үеийн тангаргийн талаар дурдахаа больж, үхэл өөр лүү нь хоёр дахь удаагаа ирэх вий гэдгээс ихэд айдаг. Миний гар дэлхий ертөнцийг өргөхөд хүмүүс баяр хөөртэйгөөр бүжиглэж, цаашид гуниглахаа болиод, бүгд Надад найддаг. Би Өөрийн гараар нүүрээ далдалж, хүмүүсийг газар доор дарахад тэдний амьсгал даруй давчдаж, бараг л амьдрах боломжгүй болдог. Өөрсдийг нь устгана хэмээн Надаас тэд бүгд айж, бүгдээрээ Намайг дуудан хашхирдаг, учир нь тэд бүгд Миний алдрыг олж авах өдрийг харахыг хүсдэг билээ. Хүн Миний өдрийг оршин тогтнолынхоо хөрөнгө гэж үздэг бөгөөд Миний алдар ирэх өдрийг хүсэн хүлээдэг учраас л хүн төрөлхтөн өнөөдрийг хүртэл амьдарсан билээ. Эцсийн өдрүүдэд төрсөн хүмүүс Миний бүх алдрыг харах хувьтай байх нь Миний амаар зарлигдсан ерөөл юм.

Эрин үеүдийн туршид олон хүн энэ дэлхийгээс гансрал гутралтайгаар, дурамжханаар явж одсон, мөн олон хүн найдвар, итгэл тээн энэ дэлхийд ирсэн. Би олон хүний ирэхийг зохицуулж, олон хүнийг явуулсан. Тоо томшгүй олон хүн Миний гараар дамжсан. Олон сүнс Үхэгсдийн орон руу хаягдаж, олон сүнс махан биед амьдарч, олон сүнс үхээд газар дээр дахин мэндэлсэн. Гэхдээ тэдний хэнд нь ч, хэзээ ч хаанчлалын ерөөлийг өнөөдөр эдлэх боломж олдоогүй. Би хүнд маш ихийг өгсөн атал тэр жаахныг олж авсан, учир нь Сатаны хүчний ширүүн дайралт түүнийг Миний бүх эд баялгийг эдэлж чадахааргүй болгож орхисон. Хүнд тэдгээрийг харах зол завшаан л байснаас биш, бүрэн эдэлж хэзээ ч чадаагүй. Хүн тэнгэрийн баялгийг хүлээн авахын тулд өөрийн бие дэх эрдэнэсийн санг хэзээ ч олж илрүүлээгүй, иймээс өөрт нь Миний хайрласан ерөөлүүдийг алдсан. Хүнийг Миний Сүнстэй холбодог чухам тэр эрхтэн нь түүний сүнс биш гэж үү? Яагаад хүн хэзээ ч сүнсээрээ Надтай холбогдоогүй юм бэ? Яагаад тэр махан биеэрээ Надад ойртож ирдэг мөртөө сүнсээрээ ойртож чаддаггүй юм бэ? Миний жинхэнэ нүүр царай бие махбодын нүүр царай юу? Хүн яагаад Миний мөн чанарыг мэддэггүй юм бэ? Миний ямар ч ул мөр хүний сүнсэнд үнэхээр хэзээ ч байгаагүй гэж үү? Би хүний сүнснээс бүрмөсөн алга болсон гэж үү? Хэрвээ хүн сүнсний ертөнцөд ордоггүй бол Миний санаа зорилгыг яаж ухаарч чадах юм бэ? Хүний нүдээр бол, сүнсний ертөнцөд шууд нэвтэрч чадах ямар нэг зүйл бий юу? Би Өөрийн Сүнсээр хүнийг дуудсан удаа олон боловч хүн Надад хутгалуулсан мэт авирлаж, өөрийг нь өөр ертөнц рүү хөтөлж аваачих вий гэсэн асар их айдастайгаар Намайг холоос ажигладаг. Би хүний сүнсэнд асуулт тавьсан удаа олон боловч тэр огт мэдэхгүй хэвээр үлдэж, Намайг гэрт нь ороод бүх эд зүйлийг нь хураан авах боломжийг ашиглана гэхээс жигтэйхэн их айдаг. Тиймээс тэр Намайг гадаа үлдээж, Надад сайтар хаасан хүйтэн хаалга л харуулдаг. Хүн унаж Би түүнийг аварсан удаа олон атал хүн сэрснийхээ дараа нэн даруй Намайг орхиж, Миний хайранд сэтгэл нь үл хөдлөн, Над руу сэрэмжилсэн харц чулууддаг; Би хүний зүрх сэтгэлийг хэзээ ч дулаацуулж байгаагүй. Хүн бол сэтгэлийн хөдөлгөөнгүй, хүйтэн цуст амьтан. Хэдийгээр Миний тэврэлт түүнийг дулаацуулдаг ч тэр үүнд хэзээ ч сэтгэл хөдөлж байгаагүй. Хүн яг л уулын зэрлэг хүн шиг. Хүн төрөлхтнийг энхрийлэн хайрладгийг минь тэр хэзээ ч нандигнаагүй. Тэр Надад ойртож ирэхийг хүсдэггүй, харин зэрлэг араатны заналхийллийг тэсвэрлэн уулсын дунд амьдрахыг илүүд үздэг—гэхдээ тэр бас Миний дотор хоргодохыг хүсдэггүй. Би ямар ч хүнийг албаддаггүй: Би ердөө Өөрийн ажлыг л хийдэг. Хүчит далайгаас хүн Над руу сэлэх өдөр лавтай ирнэ, ингэснээр тэд газар дээрх бүх эд баялгийг эдэлж, тэнгист залгиулах эрсдэлийг ардаа орхих юм.

Миний үг биелэхэд хаанчлал газар дээр аажмаар бүрэлдэж, хүн хэвийн байдалдаа аажмаар эргэн орж, улмаар Миний зүрх сэтгэл дэх хаанчлал газар дээр байгуулагддаг. Хаанчлалд Бурханы бүх ард хэвийн хүний амьдралыг эргүүлэн авдаг. Жавартай хүйтэн өвөл дуусаж, бүхэл жилийн турш хаврын улиралтай байдаг

хотуудын ертөнцөөр солигдоно. Хүмүүс дүнсгэр, тарчиг хүний ертөнцтэй нүүр тулахаа больж, хүний ертөнцийн хахир хүйтнийг туулахаа больдог. Хүмүүс бие биетэйгээ тэмцэлдэхгүй, улс орнууд өөр хоорондоо дайтахгүй, цаашид аллага хядлага ба аллага хядлагаас урсах цус гэж үгүй; бүхий л газар нутаг аз жаргалаар дүүрч, хүмүүс хоорондын халуун дулаан байдал хаа сайгүй элбэг тохиолдоно. Би дэлхий даяар явж, Өөрийн сэнтий дээр тааламжтай суун, оддын дунд амьдардаг. Тэнгэрэлчүүд Надад шинэ дуу, шинэ бүжиг өргөн барьж, дахин хэзээ ч өөрсдийнхөө хэврэг байдлын улмаас нулимс урсгахгүй. Миний өмнө тэнгэрэлчүүдийн уйлах чимээ дахин хэзээ ч сонсогдохоо больж, хэн ч Надад өөрсдийн зовлон бэрхшээлийг тоочихоо болино. Өнөөдөр та нар бүгд Миний өмнө амьдардаг; маргааш та нар бүгд Миний хаанчлалд оршино. Энэ нь хүмүүст хайрладаг хамгийн агуу ерөөл минь бус уу? Өнөөдөр төлж буй төлөөсийнхөө үрээр та нар ирээдүйн ерөөлийг өвлөн авч, Миний алдрын дунд амьдарна. Та нар Миний Сүнсний мөн чанартай холбогдохыг бас л хүсэхгүй байна уу? Та нар өөрсдийгөө хөнөөхийг хүссээр байна уу? Хүмүүс зуурдынх ч байлаа гэсэн өөрсдийн харж чадах амлалтуудын хойноос хөөцөлдөхийг хүсдэг атлаа үүрд мөнх байх маргаашийн амлалтуудыг хэн ч хүлээн авахыг хүсдэггүй. Хүнд харагддаг зүйлс бол Миний устгах зүйлс бөгөөд хүний мэдэрдэггүй зүйлс нь Миний хийж гүйцэлдүүлэх зүйлс юм. Энэ бол Бурхан, хүн хоёрын ялгаа билээ.

Хүн Миний өдөр хэзээ ирэхийг тооцоолсон ч яг тодорхой огноог хэн ч, хэзээ ч мэдээгүй, тиймээс хүн мэдээ алдсан байдал дунд л амьдарч чадна. Хүний хүсэл тэмүүлэл хязгааргүй тэнгэр даяар цуурайтаад, дараа нь алга болдог учраас хүн итгэл найдвараа ахин дахин алдаж, тэгснээр одоогийн нөхцөл байдалдаа буусан. Миний айлдваруудын зорилго бол хүнийг огноогоор хөөцөлдүүлэх биш, мөн цөхрөлийнх нь улмаас түүнийг сүйрэл рүү нь хөтлөх явдал ч биш. Би Өөрийнхөө амлалтыг хүнээр хүлээн авхуулахыг хүсдэг бөгөөд бүх дэлхий даяарх хүмүүс Миний амлалтыг хуваалцаасай гэж хүсдэг. Би амийн эрч хүчээр дүүрэн амьд амьтдыг хүсэж байгаа болохоос биш, үхэл нэвчсэн цогцоснуудыг хүсээгүй. Нэгэнт Би хаанчлалын ширээний ард заларсан учраас Миний хяналт шалгалтыг хүлээж авахыг газар дээрх бүх хүнд тушаана. Өөрийнхөө өмнө Би ямар ч бохир бузар зүйл байлгахыг зөвшөөрөхгүй. Миний ажилд ямар ч хүн хөндлөнгөөс оролцохыг Би тэвчихгүй; Миний ажилд саад учруулсан бүхэн газар доорх гяндан руу хаягдах ба суллагдсаныхаа дараа ч гай гамшигт автсан хэвээр байж, газрын төөнөсөн галыг хүлээн авна. Өөрийн махбод болсон биедээ Намайг байхад Миний ажлын талаар Миний махбодтой маргадаг хэнийг ч бай Би жигшинэ. Газар дээр хамаатан садангүй гэдгээ Би бүх хүнд сануулсан удаа олон бөгөөд Намайг өөрсөдтэйгөө эн тэнцүү мэт үзэж, өнгөрсөн үеийн талаар хамтдаа дурсахын тулд Намайг өөрсөд рүүгээ чангаасан хэн ч бай сүйрэлд өртөнө. Миний тушаадаг зүйл энэ юм. Ийм асуудлууд дээр Би хүнд өчүүхэн төдий ч хүлээцтэй хандахгүй. Миний ажилд хөндлөнгөөс оролцож, Надад зөвлөгөө өгдөг бүх хүн Надаар гэсгээгдэх бөгөөд

хэзээ ч уучлагдахгүй. Хэрвээ Би илэн далангүй ярихгүй бол хүн хэзээ ч сэхээрэхгүй бөгөөд өөрийн мэдэлгүйгээр Миний гэсгээлтэд унана—учир нь хүн махбод дахь Намайг мэддэггүй билээ.

1992 оны 3 дугаар сарын 20

21-Р БҮЛЭГ

Хүн Миний гэрлийн дунд унадаг бөгөөд Миний авралаас болж бат зогсдог. Намайг бүх орчлон ертөнцөд аврал авчрах үед хүн Миний сэргээн босголтын урсгал дунд орох арга замыг олохоор оролддог ч энэхүү сэргээн босголтын хүчтэй урсгалд ул мөргүй угаагдан арилсан олон хүн бай; хүчтэй ширүүн усны урсгалд залгигдан живсэн олон хүн бий; мөн хүчтэй ширүүн урсгал дунд бат зогсож, зүг чигийн мэдрэмжээ хэзээ ч алдалгүй, улмаар өнөөдрийг хүртэл хүчтэй урсгалыг даган яваа хүмүүс ч бас олон байдаг. Би хүнтэй хамт урагшилдаг атал хүн Намайг мөн л хэзээ ч мэдээгүй; тэрээр гаднаа өмсдөг хувцсыг минь л мэддэг боловч Миний дотор нуугдсан эд баялгийн талаар мэддэггүй. Би өдөр бүр хүнийг хангаж, түүнд өгч байдаг хэдий ч тэр жинхэнээсээ хүлээн авах чадваргүй бөгөөд Миний өгсөн бүх баялгийг авч чаддаггүй. Хүний ямар ч завхрал Надад анзаарагдалгүй өнгөрдөггүй; Миний хувьд түүний дотоод ертөнц усанд туссан тэргэл сар мэт тодорхой байдаг. Би хүнд хааш яаш ханддаггүй, мөн түүнийг аргалдаг ч үгүй; хүн зүгээр л өөрийнхөө төлөө хариуцлага хүлээх чадваргүй, тиймээс бүх хүн төрөлхтөн үргэлж доройтсоор ирсэн бөгөөд өнөөдөр ч гэсэн ийм доройтлоос бүрэн ангижрах чадваргүй хэвээр байна. Ядуу дорд, өрөвдмөөр хүн төрөлхтөн! Яагаад хүн Намайг хайрладаг ч Миний Сүнсний санаа зорилгыг дагаж чаддаггүй юм бэ? Би үнэхээр Өөрийгөө хүн төрөлхтөнд илчлээгүй гэж үү? Хүн төрөлхтөн үнэхээр Миний нүүр царайг хараагүй гэж үү? Би хүн төрөлхтөнд хэтэрхий бага өршөөл энэрэл үзүүлсэн юм гэж үү? Өө бүх хүн төрөлхтний босогчид оо! Тэд Миний хөл дор няц гишгэгдэх ёстой; тэд Миний гэсгээлт дунд замхрах ёстой бөгөөд Миний агуу ажил үйлс бүрэн дуусах өдөр хүн төрөлхтний дундаас хөөгдсөн байх ёстой, ингэснээр бүх хүн төрөлхтөн тэдний үзэшгүй муухай нүүр царайг мэднэ. Хүн Миний царайг ховорхон харж, эсвэл Миний дуу хоолойг ховорхон сонсдогийн учир нь дэлхий ертөнц тэр даяараа дэндүү оройо бусгаа, дуу шуугиан нь хэтэрхий их байдаг, тиймээс хүн Миний дүр төрхийг эрж хайхдаа, мөн Миний зүрх сэтгэлийг ойлгохоор оролдохдоо хэтэрхий хойрго байдаг. Энэ нь хүний завхралын шалтгаан биш гэж үү? Үүнээс болж хүн гачигдалтай байдаггүй гэж үү? Бүх хүн төрөлхтөн үргэлж Миний хангалт дунд байсаар ирсэн; хэрвээ тэгээгүй бол, хэрвээ Би өршөөнгүй байгаагүй бол өнөөдрийг хүртэл хэн амьд үлдэх билээ? Надад цаглашгүй их баялаг бий, гэхдээ бүх гай гамшиг ч бас Миний гарт байдаг—хэн гамшгаас хүссэн үедээ зугтаж чадах билээ?

Хүний залбирал, эсвэл түүний зүрх сэтгэл дэх уйлаан түүнд ингэх боломж олгодог гэж үү? Хүн хэзээ ч Надад үнэн голоосоо залбирч байгаагүй тул бүх хүн төрөлхтний дундаас нэг ч хүн насан туршдаа жинхэнэ гэрэлд амьдарч байгаагүй; хүмүүс анивчсан гэрэл дунд л амьдардаг. Энэ нь хүн төрөлхтний өнөөдрийн гачигдлыг бий болгосон юм.

Хүн бүр тэсэн ядан хүлээж, Надаас ямар нэгэн зүйл авахын тулд Миний төлөө бүхнээ зориулахад бэлэн байдаг тул хүний сэтгэл зүйд нийцүүлэн түүний дотор жинхэнэ хайрыг төрүүлэхийн тулд Би амлалт өгдөг. Хүнд хүч чадал өгдөг зүйл нь үнэхээр түүний жинхэнэ хайр гэж үү? Тэнгэр дэх Миний Сүнсийг хөдөлгөсөн зүйл нь хүний Надад өгсөн үнэнч байдал гэж үү? Хүний үйлдлүүд тэнгэрт өчүүхэн төдий ч нөлөөлж байгаагүй бөгөөд хүнд хандах Миний хандлага түүний үйлдэл бүрд суурилдаг байсан бол бүх хүн төрөлхтөн Миний гэсгээлт дунд амьдрах байсан юм. Нулимс хацрыг нь даган урсах олон хүнийг Би харсан бөгөөд Миний эд баялгийн хариуд зүрх сэтгэлээ өргөн барьсан олон хүнийг харсан. Тийм “үнэн сүсэгтэй байдал”-ыг үл харгалзан Би хүний гэнэтийн хүсэл эрмэлзлийн үр дүнд Өөрт байгаа бүхнийг хэзээ ч чөлөөтэй өгөөгүй, учир нь хүн Миний өмнө өөрийгөө баяртайяа зориулахад хэзээ ч бэлэн байгаагүй билээ. Би бүх хүн төрөлхтний багийг хуулж, эдгээр багийг галт нууранд хаясан, үүний үр дүнд хүний хэлдэг үнэнч байдал болон гуйлт Миний өмнө хэзээ ч бат зогсоогүй. Хүн яг л тэнгэр дэх үүл шиг: Салхи улихад хүн хүчнээс нь эмээдэг учраас үүний дараагаар яаран хөвж, дуулгаваргүй байдлаасаа болоод бут ниргүүлэх вий хэмээн ихэд айдаг. Энэ нь хүний үзэшгүй муухай нүүр царай биш гэж үү? Энэ нь хүний дуулгавартай байдал гэгч биш гэж үү? Энэ нь хүний “чин сэтгэл” болон хуурамч сайхан сэтгэл биш гэж үү? Олон хүн Миний амнаас гарсан бүх айлдварт үнэмшихээс татгалздаг бөгөөд олон хүн Миний үнэлгээг хүлээн зөвшөөрдөггүй, иймээс тэдний үг болон үйлдэл урвах санаа зорилгыг нь илчилдэг. Миний ярьдаг зүйл хүний хуучин уг чанарын эсрэг байдаг уу? Би “байгалийн хуулийн” дагуу зохих тодорхойлолтыг хүнд өгөөгүй гэж үү? Хүн Надад үнэнээсээ дуулгавартай байдаггүй; хэрвээ тэр үнэхээр Намайг хайсан бол Би ийм ихийг хэлэх хэрэггүй байх байсан юм. Хүн бол үнэ цэнгүй хог шаар бөгөөд Би түүнийг албан хүчээр урагшлуулахын тулд Өөрийн гэсгээлтийг ашиглах ёстой; хэрвээ Би ийнхүү хийгээгүй бол Миний өгсөн амлалт түүний зугаа цэнгэлд хангалттай байсан ч гэсэн—түүний зүрх сэтгэлийг хөдөлгөж чадах байсан уу? Хүн олон жилийн турш шаналгаат тэмцлийн дунд үргэлж амьдарсан; тэр үргэлж цөхрөл дунд амьдарсан гэж хэлж болно. Үүний үр дүнд тэрээр бухимдалтай үлдэж, бие сэтгэлээрээ ядарч туйлдсан тул түүнд Миний өгдөг бүх эд баялгийг баяртайгаар хүлээн авдаггүй. Өнөөдөр ч гэсэн хэн ч Надаас сүнсний бүх сайхан амтыг хүлээн авч чаддаггүй. Хүмүүс гагцхүү ядуу хэвээр үлдэж, сүүлчийн өдрийг хүлээж л чадна.

Олон хүн Намайг үнэн голоосоо хайрлахыг хүсдэг боловч тэдний зүрх сэтгэл өөрсдийнх нь биш учраас өөрсдийгөө хянах аргагүй байдаг; олон хүн Миний өгсөн шалгалтыг тууланга Намайг үнэхээр хайрладаг ч үнэхээр оршин байдаг гэдгийг

минь ухаарах чадваргүй байдаг бөгөөд бодит оршин тогтнолоос минь болоод биш, ердөө л хоосон байдал дунд Намайг хайрладаг; олон хүн зүрх сэтгэлээ Миний өмнө дэлгээд, дараа нь зүрх сэтгэлдээ ямар ч анхаарал хандуулдаггүй, тиймээс боломж олдонгуут л Сатан тэдний зүрх сэтгэлийг булаан авдаг ба тэгээд тэд Намайг орхидог; Намайг үгээрээ хангахад олон хүн үнэн голоосоо Намайг хайрладаг ч Миний үгийг сүнсэндээ нандигнадаггүй, харин тэдгээрийг нийтийн өмч шиг хааш яаш ашиглаж, хүссэн үедээ ирсэн газар луу нь эргүүлээд шиддэг. Хүн зовлон шаналал дунд Намайг хайж, шалгалтан дунд Намайг бишрэн хардаг. Амар тайван цаг үед тэр Намайг таашаадаг, аюул осол дунд Намайг үгүйсгэдэг, завгүй байх үедээ Намайг мартаж, завтай үедээ Миний төлөө хийсэн дүр үзүүлдэг—гэсэн ч хэзээ ч, хэн ч Намайг насан туршдаа хайрлаж байгаагүй. Хүн Миний өмнө чин үнэнч байгаасай гэж Би хүсдэг: Надад ямар нэгэн зүйл өгөхийг Би хүнээс шаарддаггүй, харин бүх хүн Намайг ноцтойгоор авч үзэж, Намайг аргалахын оронд хүний чин сэтгэлийг буцаан авчрах боломжийг Надад олгохыг л шаарддаг. Миний гэгээрэл, гэрэлтүүлэлт болон хүчин чармайлтын минь үнэ цэн бүх хүнд шингэдэг, гэвч хүний үйлдэл болгоны үнэн бодит байдал ч бас бүх хүнд шингэж, Намайг хуурах тэдний хууран мэхлэлт ч шингэдэг. Хүний хууран мэхлэлтийн орц найрлагууд эхийн хэвлийд байхаас нь түүнд байсан мэт, төрсөн цагаасаа хойш эдгээр онцгой заль мэхний чадварыг эзэмшсэн мэт байдаг. Үүнээс гадна, тэрээр энэ тоглоомд хэзээ ч бууж өгөөгүй; эдгээр зальжин ур чадварын эх үүсвэрийг хэн ч, хэзээ ч нэгд нэггүй хараагүй. Үүний үр дүнд хүн өөрийн мэдэлгүй хууран мэхлэлт дунд амьдардаг ба тэр өөрийгөө уучилдаг юм шиг, Намайг зориуд хуурдаг гэхээсээ илүү энэ нь Бурханы зохицуулалт юм шиг байдаг. Энэ нь Намайг мэхлэх хүний хууран мэхлэлтийн жинхэнэ эх сурвалж биш гэж үү? Энэ нь түүний зальхай арга ухаан биш гэж үү? Би хүний ов заль болон бялдуучлалаас болж хэзээ ч будилаагүй, учир нь Би олон жилийн өмнө түүний гол чанарыг ойлгож авсан юм. Түүний цусанд хэр их хольц байдгийг болон түүний чөмгөн дотор Сатаны хэр их хор байдгийг хэн мэдэх билээ? Хүн Сатаны учруулсан хор хөнөөлийг мэдрэхээ болих хүртлээ өдөр ирэх тусам үүнд дасдаг, тиймээс “эрүүл оршин тогтнох урлагийг” олж мэдэх ямар ч сонирхолгүй байдаг.

Хүн Надаас хол байх үед, Намайг турших үед Би үүлсийн дунд Өөрийгөө түүнээс нуудаг. Үүний үр дүнд тэр Миний ямар ч ул мөрийг олж чаддаггүй бөгөөд зөвхөн хорон муу нэгний гарт, хүссэн бүхнийг нь хийж амьдардаг. Хүн Надад ойр байх үед Би түүнд харагддаг бөгөөд түүнээс Өөрийн царайг нуудаггүй, энэ үед хүн Миний эелдэг төрх байдлыг хардаг. Тэр гэнэт сэхээрч, нэг л мэдэхэд түүнд Намайг гэх хайр төрдөг. Зүрх сэтгэлдээ тэр зүйрлэшгүй сайхныг мэдэрч, орчлон ертөнц дэх Миний оршин тогтнолыг мэдэхгүй явж байснаа гайхдаг. Тиймээс ч хүн Миний хайр татам байдлыг, түүнчлэн Миний эрхэм нандин байдлыг илүү их мэдэрдэг. Үүний үр дүнд тэр Намайг дахин хэзээ ч орхихгүй байхыг хүсэж, Намайг өөрийнх нь амьдралын гэрэл гэж үздэг бөгөөд өөрийг нь орхих вий гэдгээс ихэд айсандаа

Намайг чанга тэвэрдэг. Хүний урам зоригоос болж Миний сэтгэл хөдөлдөггүй, харин хайраас нь болж Би түүнд өршөөнгүй ханддаг. Энэ мөчид хүн даруй Миний шалгалтын дунд амьдардаг. Миний нүүр царай түүний зүрх сэтгэлээс алга болж, амьдрал нь тэр даруй хий хоосон санагдаж, зугтах бодол төрдөг. Энэ мөчид хүний зүрх сэтгэл ил болдог. Миний зан чанараас болоод тэр Намайг тэвэрдэггүй, харин Өөрийнхөө хайраас болж түүнийг хамгаалахыг Надаас гуйдаг. Гэсэн ч Миний хайр хүнийг буцаан цохих үед тэрээр бодлоо даруйхан өөрчилдөг; тэр Надтай байгуулсан гэрээгээ урж хаяад, Миний өршөөнгүй царайг дахин хэзээ ч харахыг хүсэхгүйгээр Миний шүүлтээс зугтаадаг тул Миний талаарх үзэл бодлоо өөрчилж, Намайг хэзээ ч хүнийг аварч байгаагүй хэмээн хэлдэг. Жинхэнэ хайранд гагцхүү өршөөл л байдаг гэж үү? Миний гялалзах гэрэл дор амьдарч л байвал хүн Намайг хайрладаг уу? Тэрээр өчигдрийг эргэн санадаг ч өнөөдөртөө амьдардаг—энэ нь хүний нөхцөл байдал биш гэж үү? Та нар үнэхээр маргааш ч гэсэн энэ хэвээрээ байх уу? Хүн өнгөц байдлаар Намайг сэтгэл хангалуун болгодог биш, харин үнэн голоосоо Намайг хүсэн эрмэлздэг зүрх сэтгэлтэй байгаасай гэж л Би хүсдэг.

1992 оны 3 дугаар сарын 21

22-Р БҮЛЭГ

Хүн гэрэл дунд амьдардаг боловч гэрлийн эрхэм нандиныг мэддэггүй. Тэр гэрлийн мөн чанар, гэрлийн эх сурвалж, түүнчлэн гэрэл хэнд харьяалагддагийг мэддэггүй. Хүмүүсийн дунд гэрэл өгөхдөө Би тэдний дундах нөхцөл байдлыг нэн даруй шинжилдэг: Гэрлээс болж бүх хүн өөрчлөгдөж, өсөж байгаагийн дээр харанхуйг орхисон. Би орчлон ертөнцийн өнцөг булан бүрийг ажиглаж, уулс мананд бүрхэгдсэнийг, ус хүйтэнд хөлдсөнийг, мөн гэрэл ирснээс болоод хүмүүс илүү эрхэм зүйлийг олж мэдэж магад гэсэндээ Зүүн зүг рүү харахыг үзсэн—гэсэн ч хүн будан дундаас тодорхой зүг чигийг ялган харж чадахгүй хэвээр үлдсэн юм. Бүхий л дэлхий мананд хучигдсан учраас үүлсийн дундаас харахад минь хэн ч, хэзээ ч Миний оршин тогтнолыг олж мэдээгүй. Хүн газар дэлхий дээр ямар нэг зүйлийг эрж хайж байгаа; тэр хоол хүнс хайж байгаа мэт санагддаг; мөн Миний ирэхийг хүлээхээр санаархаж байгаа мэт харагддаг—гэсэн ч тэр Миний өдрийг мэддэггүй, Зүүн зүгт сүүмэлзэх гэрэл рүү байн байн харж л чадна. Би бүх хүний дундаас Миний зүрх сэтгэлд үнэхээр нийцдэг хүмүүсийг эрж хайдаг. Би бүх ард түмний дунд алхаж, бүх ард түмний дунд амьдардаг ч хүн газар дээр эсэн мэнд, эрүүл саруул байдаг болохоор Миний зүрх сэтгэлд үнэхээр нийцдэг хэн ч үгүй. Хүмүүс Миний хүслийг хэрхэн анхаарахаа мэддэггүй, Миний үйлдлийг харж чаддаггүй ба гэрлийн дотор алхаж, гэрлийн тусгалд байж чаддаггүй. Хэдийгээр хүн Миний үгийг үргэлж эрхэмлэдэг ч Сатаны зальжин арга мэхийг нэвт харах чадваргүй; хүний биеийн

хэмжээ хэтэрхий жижиг учраас зүрх сэтгэлдээ хүссэнээ хийж чаддаггүй. Хүн Намайг хэзээ ч чин сэтгэлээсээ хайрлаж байгаагүй. Түүнийг өргөмжлөх үед минь тэр үнэ цэнгүйгээ мэдэрдэг боловч үүнээсээ үүдэн Миний сэтгэлийг хангалуун байлгахаар хичээдэггүй. Тэр зүгээр л Миний өгсөн “байр суурийг” гартаа бариад шинжилдэг; Миний хайр татам байдалд мэдрэмжгүй хандаж, харин өөрийн байр суурийн ашиг тусад шунан зүтгэдэг. Энэ нь хүний дутагдал бус уу? Уулс нүүхдээ чиний байр суурийн төлөө тойруу замаар явж болно гэж үү? Ус урсахдаа хүний байр суурийн өмнө урсахаа больж болно гэж үү? Тэнгэр, газар хүний байр сууриас болж орвонгоороо эргэж болно гэж үү? Би нэгэнтээ хүнд ахин дахин өршөөнгүй хандаж байсан—гэтэл хэн ч үүнийг эрхэмлэн нандигнаагүй. Тэд үүнийг зүгээр л түүх мэт сонссон, эсвэл тууж шиг уншсан. Миний үг хүний зүрх сэтгэлийг үнэхээр хөдөлгөдөггүй юм гэж үү? Миний айлдвар үнэхээр ямар ч үр нөлөөгүй гэж үү? Нэг ч хүн Миний оршин тогтнолд итгэдэггүй юм гэж үү? Хүн өөрийгөө хайрладаггүй; харин ч Над руу дайрч давшлахын тулд Сатантай нэгдэж, Сатаныг Надад үйлчлэх “хөрөнгө” болгон ашигладаг. Би Сатаны бүх зальжин явуулгыг нэвт харж, газар дэлхийн хүмүүс Сатаны хууран мэхлэлтийг хүлээн авдгийг болиулна, ингэснээр тэд Сатаны оршин тогтнолоос болж Намайг эсэргүүцэхгүй.

Хаанчлалд Би бол Хаан—гэхдээ Надад Хаан шиг хандахын оронд хүн Надтай “тэнгэрээс бууж ирсэн Аврагч” шиг харьцдаг. Үүний улмаас өөрт нь өглөг өгөхийг тэр Надаас хүсэн хүлээж, Намайг мэдэхээр эрж хайдаггүй. Маш олон хүн Миний өмнө гуйлгачин шиг гуйж гувшсан; маш олон хүн Надад “хүүдийгээ” нээж, амь зуух хоол өгөхийг гуйсан; маш олон хүн өлсгөлөн чоно адилаар шуналт харцаа Над дээр тогтоож, Намайг ховдоглон идэж, ходоодоо дүүргэхийг хүссэн; маш олон хүн гэм буруугаасаа болоод чимээгүйхэн толгойгоо гудайлган ичиж, Миний өршөөл энэрлийг гуйн залбирсан, эсвэл Миний гэсгээлтийг дуртайяа хүлээн зөвшөөрсөн. Намайг айлдах үед хүний янз бүрийн тэнэг авир шал утгагүй санагддаг ба түүний жинхэнэ төрх гэрэл дунд илчлэгддэг; тэгээд гялалзсан гэрэлд хүн өөрийгөө уучилж чаддаггүй. Тиймээс тэр Миний өмнө яаран ирж, бөхийгөөд нүглээ улайдаг. Хүний “үнэнч шударга зангаас” болж Би түүнийг авралын тэргэн дээр дахин нэг удаа татан гаргасан, тиймээс хүн Надад талархаж, Над руу хайрын харц чулууддаг. Гэсэн ч тэр үнэхээр Надад хоргодох дургүй хэвээр байдаг бөгөөд зүрх сэтгэлээ Надад бүрэн өгөөгүй. Тэр зүгээр л Надаар бардамнан сайрхдаг ч Намайг үнэхээр хайрладаггүй, учир нь хүн оюун ухаанаа Надад хандуулаагүй; түүний бие Миний өмнө байдаг ч зүрх сэтгэл нь Миний ард байдаг. Дүрэм журмын талаарх хүний ойлголт хэт дульхан, мөн тэр Миний өмнө ирэх ямар ч сонирхолгүй байдаг учраас Би түүнийг зохих дэмжлэгээр хангадаг, ингэснээр тэр гөжүүд мэдлэггүй байдлынхаа дундаас Над руу эргэж магад юм. Энэ нь хүнд Миний өгдөг яг тэр өршөөл бөгөөд хүнийг аврахаар хичээдэг Миний арга барил билээ.

Орчлон ертөнц дахины хүмүүс Миний өдөр ирснийг тэмдэглэж, тэнгэрэлчүүд Миний бүх ардын дунд алхдаг. Сатан төвөг учруулах үед тэнгэр дэх үйлчлэлээсээ

болоод тэнгэрэлчүүд Миний ардуудад үргэлж тусалдаг. Тэд хүний сул талаас болж диаволд хууртдаггүй, харин харанхуйн хүчний дайралтаас үүдэн манан дунд хүний амьдралыг туулахаар бүр ч их чармайдаг. Бүх хүн Миний нэрийн дор захирагддаг бөгөөд Намайг илт эсэргүүцэхээр хэн ч, хэзээ ч өндийн босдоггүй. Тэнгэрэлчүүдийн хөдөлмөрөөс үүдэн хүн Миний нэрийг хүлээн зөвшөөрдөг ба бүгд Миний ажлын урсгал дунд байдаг. Дэлхий ертөнц нуран унаж байна! Вавилон саажилттай байна! Өө, шашны ертөнц! Газар дээрх Миний эрх мэдлээс болж устахгүй байж яаж чадах билээ? Хэн Надад дуулгаваргүй хандаж, Намайг эсэргүүцсээр байж зүрхлэх билээ? Хуулийн багш нар уу? Шашны албан тушаалтан болгон уу? Газар дээрх захирагчид, эрх мэдэлтнүүд үү? Тэнгэрэлчүүд үү? Миний биеийн төгс, бүрэн байдлыг хэн баярлан тэмдэглэдэггүй вэ? Бүх хүний дундаас хэн Намайг тасралтгүй магтаж, хэн дуусашгүй аз жаргалтай байдаггүй вэ? Би агуу улаан лууны ичээ буй газар нутагт амьдардаг ч энэ нь Намайг айн чичирч, эсвэл зугтахад хүргэдэггүй, учир нь түүний хүмүүс бүгд аль хэдийн түүнийг үзэн ядаж эхэлсэн. Лууны төлөө, лууны өмнө юу ч, хэзээ ч “үүргээ” биелүүлж байгаагүй; харин ч бүх зүйл зохистой гэж үзсэнээ хийж, дор бүрнээ өөрсдийнхөө замаар явдаг. Газар дээрх улс орнууд мөхөхгүй байж яахан чадах билээ? Газар дээрх улс орнууд нуран унахгүй байж яахан чадах билээ? Миний ардууд баярлан хөөрөхгүй байж яахан чадах билээ? Тэд баяр баясалтайгаар дуулахгүй байж яахан чадах билээ? Энэ нь хүний ажил уу? Хүний гараар хийгдсэн зүйл үү? Би хүнд оршин тогтнолынх нь үндсийг өгч, түүнийг материаллаг зүйлээр хангасан, гэсэн ч хүн одоогийн нөхцөл байдалдаа сэтгэл ханадаггүй бөгөөд Миний хаанчлалд оръё гэж гуйдаг. Гэвч төлөөс төлөхгүйгээр, өөрийгөө амь бие хайргүй зориулахыг хүсэхгүйгээр хүн яаж Миний хаанчлалд тийм амархан орж чадах билээ? Хүнээс ямар нэг зүйлийг хатуу нэхэхийн оронд Би газар дээрх Өөрийн хаанчлалыг алдраар дүүргэхийн тулд хүнд шаардлага тавьдаг. Хүн өнөөг хүртэл Надаар замчлуулсан бөгөөд ийм нөхцөл байдалд оршиж, Миний гэрлийн удирдамж дунд амьдардаг. Хэрвээ ийм байгаагүй сэн бол газар дээрх хүмүүсээс хэн өөрсдийн хэтийн ирээдүйг мэдэх билээ? Хэн Миний хүслийг ойлгох билээ? Би хүнд тавих шаардлагадаа Өөрийн хангалтыг нэмдэг; энэ нь байгалийн хуультай нийцдэг бус уу?

Өчигдөр та нар салхи, бороон дунд амьдарсан; өнөөдөр Миний хаанчлалд орж, хаанчлалын ардууд болсон; маргааш та нар Миний ерөөлийг эдэлнэ. Хэн ер нь ийм зүйлсийг төсөөлж байсан бэ? Та нар амьдралдаа хэчнээн их саад тотгор, зовлон бэрхшээл туулах вэ—та нар мэдэх үү? Салхи бороон дунд Би урагшилж, жил бүрийг хүмүүсийн дунд өнгөрөөж, өнөө үед ирлээ. Эдгээр нь чухамдаа Миний удирдлагын төлөвлөгөөний алхмууд биш гэж үү? Миний төлөвлөгөөнд хэн ер нь нэмэрлэсэн билээ? Миний төлөвлөгөөний алхмуудаас хэн зугтаж чадах билээ? Би хэдэн зуун сая хүний зүрх сэтгэлд амьдардаг, Би бол хэдэн зуун сая хүний дундах Хаан бөгөөд Би хэдэн зуун сая хүнд гологдож, доромжлуулж ирсэн. Миний дүр хүмүүсийн зүрх сэтгэлд үнэхээр байдаггүй. Хүн Миний үгээс Миний алдар суутай

төрхийг бүүр түүрхэн л мэдэрдэг боловч бодол нь үймэрдгээс болоод өөрийн мэдрэмжид итгэдэггүй; түүний зүрх сэтгэлд тодорхойгүй Би л байдаг боловч тэндээ удаан байдаггүй. Иймээс Намайг хайрлах түүний хайр ч бас ийм байдаг: Хүн болгон Намайг өөрсдийнхөө зан аашийн дагуу хайрласан мэт, сарны бүүдгэр гэрэлд түүний хайр анивчиж байсан мэт Миний өмнө түүний хайр тасалдан харагддаг. Өнөөдөр Миний хайраас л болж хүн үлдэж, амьд үлдэх сайн аз завшаантай болсон. Хэрвээ тэгээгүй бол, турж эцсэн биеэсээ болоод хүмүүсийн дотроос хэн лазерын туяанд хэрчигдэхгүй байх билээ? Хүн одоо ч өөрийгөө мэддэггүй. Тэр Миний өмнө гайхуулж, Миний нүднээс далдуур сайрхдаг, гэхдээ Миний өмнө хэн ч Намайг эсэргүүцэж зүрхэлдэггүй. Гэсэн ч хүн Миний ярьдаг эсэргүүцлийн утга учрыг мэддэггүй; харин ч Намайг хуурах гэж оролдсоор, өөрийгөө өргөмжилсөөр байдаг—ингэснээрээ тэр Намайг илт эсэргүүцдэг бус уу? Би хүний сул талуудыг тэвчдэг боловч хүний гаргасан эсэргүүцэлд өчүүхэн төдий ч өршөөнгүй ханддаггүй. Хэдийгээр тэр утгыг нь мэддэг ч энэ утгын дагуу үйлдэхийг хүсдэггүй ба зүгээр л өөрийнхөө дур сонирхлын дагуу үйлдэн, Намайг мэхэлдэг. Би Өөрийн зан чанарыг цаг үргэлж үгээрээ тодорхой болгодог атал хүн ялагдалтай эвлэрдэггүй—үүний зэрэгцээ өөрийн зан чанарыг илчилдэг. Миний шүүлтийн дунд хүн бүрэн үнэмшиж, Миний гэсгээлтийн дунд эцэстээ Миний дүрийг амьдран харуулж, газар дээрх Миний илрэл болно!

1992 оны 3 дугаар сарын 22

23-Р БҮЛЭГ

Амнаас минь дуу гарч, нүднээс минь гал бадран, Би дэлхийг бүхэлд нь харж, орчлон ертөнцийг бүхэлд нь ажиглаж байна. Бүх хүн Надад залбирч, харцаа Миний зүг хандуулаад уур хилэнгээ зогсоогооч хэмээн Намайг царайчлан гуйж, Миний эсрэг дахин тэрслэхгүй гэж амлаж байна. Гэвч энэ нь өнгөрсөн үе байхаа больсон; энэ бол одоо үе. Миний хүслийг хэн эргүүлж чадах билээ? Хүний зүрх сэтгэл дэх залбирал ч, тэдний амнаас гарсан үг ч тэгж чадахгүй нь лавтай биз дээ? Намайг байгаагүй бол хэн өнөөг хүртэл амьд үлдэж чадах байсан билээ? Миний амнаас гарсан үгээс болж амьдардаггүй хэн байх билээ? Миний нүдэнд харагддаггүй хэн байх билээ? Намайг шинэ ажлаа дэлхий даяар хэрэгжүүлж байхад хэн ер нь үүнээс зугтаж чадсан билээ? Уулс өндрийнхөө хүчээр үүнээс бултан зайлж чадах уу? Ус энгүй уудмаараа үүнийг няцаан зайлуулж чадах уу? Би төлөвлөгөөндөө юуг ч, хэзээ ч хөнгөн хуумгай орхидоггүй, тиймээс нэг ч хүн, нэг ч зүйл Миний гарын эрхшээлээс хэзээ ч зайлж байгаагүй. Өнөөдөр бүх хүн Миний ариун нэрийг шагшин магтаж, бас Намайг эсэргүүцсэн үг бүх хүний дунд ихсэж, газар дэлхий дээр Миний байгаа тухай домгууд бүх хүний дунд түгжээ. Хүмүүс Намайг шүүмжлэхийг Би тэвчдэггүй,

Миний биеийг хуваахыг нь ч тэвчдэггүй бөгөөд Намайг харааж зүхэхийг нь бүр ч тэвчдэггүй. Хүн Намайг хэзээ ч үнэхээр мэдэж байгаагүй учраас Намайг үргэлж эсэргүүцэж, мэхэлдэг ба Миний Сүнсийг нандигнах юм уу Миний үгийг эрхэмлэж чаддаггүй. Үйл хэрэг, үйлдэл бүрийнх нь хариуд, Надад хандах хандлагынх нь хариуд Би хүнд зохих “шагналыг” нь хүртээдэг. Иймээс хүмүүс бүгдээрээ шагнал горилж ажилладаг бөгөөд хэн ч, хэзээ ч өөрийгөө золиослохтой холбоотой ажил хийгээгүй. Хүмүүс амь биеэ үл хайрлан зүтгэхийг хүсдэггүй, харин өртөг зардалгүй хүртэж болох шагналд дурладаг. Петр Миний өмнө өөрийгөө зориулсан хэдий ч энэ нь маргаашийн шагналын төлөө бус, харин өнөөдрийн мэдлэгийн төлөө байв. Хүмүүс хэзээ ч Надтай үнэн голоосоо ярилцаагүй, харин Надтай үе үе өнгөцхөн байдлаар харьцаж, тэгснээрээ Миний сайшаалыг төвөггүй олж авна гэж бодсон. Би хүний зүрх сэтгэлийн гүнийг хараад далдын далд байдаг “олон баялгийн уурхайг” нь ухаж гаргасан ба тэр зүйлийг хүн өөрөө ч хараахан мэдээгүй, харин Би шинээр олж илрүүлсэн юм. Иймээс хүн “баримт нотолгоо” харах үедээ л хуурамчаар өөрийгөө дорд үзэхээ больдог бөгөөд гараа сарвайж, өөрийн бузар байдлыг хүлээн зөвшөөрдөг. Бүх хүний таашаалд зориулан Надаар “олборлуулах” гээд хүлээж буй шинэ сэргэг зүйл хүмүүсийн дунд хавьгүй олон байдаг. Би хүний чадваргүй байдлаас болоод Өөрийнхөө ажлыг зогсоох нь байтугай, анхны төлөвлөгөөнийхөө дагуу хүнийг засдаг. Хүн бол жимсний модтой адил: Засаж янзлахгүй бол тэр модонд жимс ургахгүй, эцэстээ газар унах нэг ч жимсгүй, хатаж хувхайрсан навч, мөчир л харагдана.

Би Өөрийн хаанчлалын “дотоод өрөөг” өдрөөс өдөрт чимэглэж байхад хэн ч, хэзээ ч Миний ажлыг тасалдуулахаар “ажлын өрөө” рүү минь гэнэт дайран орж байгаагүй. Бүх хүн “ажлаас халагдан”, “албан тушаалаа алдаж”, улмаар амьдралдаа мухардалд орж, Сатаны булаан эзэлсэн “цөлд” ч унаж магадгүй гэж ихэд айсандаа Надтай хамтран ажиллахаар хамаг байдгаараа хичээж байна. Хүний айдсаас болоод Би түүнийг өдөр бүр тайтгаруулж, өдөр бүр хүний хайрыг өдөөж, түүнчлэн өдөр тутмынх нь амьдралд заавар өгдөг. Хүмүүс бүгдээрээ дөнгөж төрсөн нярай хүүхэд шиг байдаг; сүү өгөхгүй л бол тэд энэ газар дэлхийг төдхөн орхиж, дахин үзэгдэхээ болино. Хүмүүсийн гуйлтан дунд Би хүний ертөнцөд ирж, хүмүүс тэр дороо гэрлийн ертөнцөд амьдардаг ба нэг “өрөөнд” хашигдаад тэндээсээ тэнгэрт залбиран хашхирахаа больдог. Хүмүүс Намайг хармагцаа зүрх сэтгэлдээ хадгалсан “гомдлоо” даруй гаргаж, аманд нь хоол хийгээч гэж гуйх гээд Миний өмнө амаа ангайдаг. Гэвч дараа нь айдас нь дарагдаж, тайвшраад, Надаас юу ч гуйхаа больдог, харин бөх унтах юм уу Миний оршин тогтнолыг үгүйсгэн өөрсдийнхөө хэрэг явдлыг анхаарч эхэлдэг. “Сэтгэл хөдлөл”-гүй хүмүүс өөрсдийнхөө “шударга ёсыг” Надад яаж хэрэгжүүлдгийг хүн төрөлхтний “орхин явах”-аас тодорхой харж болно. Тийм учраас хүний энэ онцгүй талыг хараад Би чимээгүйхэн явж оддог бөгөөд түүнийг чин сэтгэлээсээ гуйж гувшихад нь амархан бууж ирэхээ болино. Хүний бэрхшээл өөрийн мэдэлгүй өдрөөс өдөрт ихэсдэг тул

хүнд хүчир ажил хөдөлмөрийнхөө дунд Миний оршин тогтнолыг гэнэт олж мэдэх үедээ тэрээр “үгүй” гэж хэлэхийг минь зөвшөөрөлгүй Намайг заамдаж аваад өөрийнхөө гэрт зочин мэт оруулдаг. Гэхдээ тэр Надад зориулан тансаг сайхан хоол бэлдэн барьж болох ч Намайг ганц удаа ч гэсэн өөрийнхнийх нь нэг гэж тооцоогүй, харин Надаас багахан тусламж олж авахын тулд Надад зочин мэт ханддаг. Иймээс энэ удаа хүн өрөвдөлтэй байдлаа Миний өмнө эрээ цээргүй дэлгээд, бизнесийн зээлд хэрэгтэй байдаг шиг “гарын үсгийг” минь авна гэж горьдон, Намайг хамаг чадлаараа “хоргоодог”. Би хүний дохио зангаа, үйл хөдлөл бүрээс санаа зорилгыг нь бүүр түүрхэн мэдэрдэг: Түүний бодлоор бол Би нүүр царайных нь илэрхийлэлд нуугдсан, үгийнх нь цаана далдлагдсан утгыг тааварлаж мэдэхгүй, эсвэл хүний зүрх сэтгэлийн гүнийг хэрхэн харахаа мэддэггүй юм шиг л байдаг. Иймээс хүн туулсан туршлага бүрийг алдаа мадаггүй, юу ч орхилгүйгээр Надад нэгд нэггүй аминчлан хэлдэг бөгөөд дараа нь Миний өмнө шаардлагаа дэлгэж тавьдаг. Би хүний үйл хэрэг, үйлдэл бүрийг үзэн ядаж, жигшдэг. Хүмүүсийн дундаас Миний дуртай ажлыг хийсэн ганц ч хүн хэзээ ч байгаагүй ба хүмүүс Надад зориуд дайсагнаж, уур хилэнг минь санаатайгаар өөртөө татаж буй мэт байдаг: Тэд бүгдээрээ Миний өмнүүр урагш, хойш алхаж, Миний нүдэн дээр өөрсдийн хүслийг өөгшүүлдэг. Хүмүүсийн дунд Миний төлөө амьдардаг ганц ч хүн байдаггүй, үүний уршгаар бүх хүн төрөлхтний амьдрал үнэ цэн ч үгүй, утга учир ч үгүй болж, хүн төрөлхтнийг хоосон орон зайд амьдрахад хүргэдэг. Тэгсэн мөртөө л хүн сэрэхээс бас л татгалзаж, Миний эсрэг тэрсэлсээр, үргэлжлүүлэн хий хоосон амьдардаг.

Давж туулсан бүх шалгалтдаа хүмүүс хэзээ ч Миний сэтгэлд нийцэж байгаагүй. Харгис шударга бус байдлаасаа болж хүн төрөлхтөн Миний нэрийг гэрчлэхээр зорьдоггүй; харин ч амин зуулгаа Надад найдчихаад “өөр замаар гүйдэг”. Хүний зүрх сэтгэл Над руу бүрэн эргээгүй тул Сатан түүнийг яр шарханд нэрвэгдэж, хамаг бие нь бохир заваанаар бүрхэгдтэл гишгэлдэг. Гэвч нүүр царай нь хэчнээн ой гутам байгааг хүн бас л ухаардаггүй: Миний ар хударгаар Сатаныг шүтсээр байдаг. Энэ шалтгааны улмаас Би хүнийг ёроолгүй нүхэнд хилэгнэн хаяж, өөрийгөө хэзээ ч чөлөөлж чадахааргүй болгосон. Тэгсэн ч гэсэн, гашуудан уйлж байхдаа хүн бас л оюун санаагаа өөрчлөхөөс татгалзан, Намайг эцсээ хүртэл эсэргүүцэхээр санаархаж, улмаар Миний уур хилэнг зориуд өдөөхөөр найддаг. Хийсэн зүйлээс нь болоод Би хүнийг нүгэлтэн хэмээн үзэж, халуун дулаанаар тэврэхээс татгалздаг. Анхнаасаа тэнгэрэлчүүд Надад тууштай, зогсолтгүй үйлчилж, дуулгавартай байсан, гэвч хүн Надаас гараагүй, харин Сатанаас төрсөн юм шиг л ямагт яг эсрэгээр нь хийдэг байлаа. Тэнгэрэлчүүд бүгдээрээ тус тусын байранд Надад хамаг зүтгэлээ зориулдаг; тэд Сатаны хүчинд үл ганхан, үүргээ л биелүүлдэг. Тэнгэрэлчүүдээр угжуулж, тэжээлгэсэн Миний үй олон хөвгүүн, Миний ардууд бүгд эрүүл, чийрэг торнин өсдөг, тэдний дунд сул дорой нэг ч хүн үгүй. Энэ бол Миний үйл, Миний гайхамшиг. Миний хаанчлал байгуулагдсаныг ёслон их буугаар удаа дараалан галлахад тэнгэрэлчүүд айзамт хөгжмийн аясаар алхан Миний үзлэгт

орохоор Миний индрийн өмнө ирнэ, учир нь тэдний зүрх сэтгэл хольц, шүтээнээс ангид бөгөөд Миний үзлэгээс дөлж зайлсхийдэггүй.

Хүчтэй салхи исгэрэн улихад тэнгэрүүд хоромхон зуур доош буун ирж, бүх хүн төрөлхтний амьсгааг боодог тул хүмүүс Намайг хүссэнээрээ дуудаж чадахаа больдог. Үүнийг мэдэлгүй бүх хүн нуран унасан. Модод салхинд нааш цааш найгаж, үе үе мөчир чадхийх сонсогдоод хатаж гандсан навчис бүгд хийсэн одно. Газар дэлхий гэнэтхэн хүйтэн, эзгүй санагдах бөгөөд хүмүүс намрын дараа хэзээ хэзээгүй нөмрөн ирэх гай гамшгийг хүлээн биеэ хураадаг. Шувууд толгод дээгүүр нааш цааш нисэлдэх нь уй гашуугаа хэн нэгэнд хашхиран өгүүлэх мэт; уулын агуйд арслан архирах нь чөмөг нь царцаж, толгойтой үс нь бостол хүмүүсийг айлгадаг бөгөөд хүн төрөлхтний төгсгөлийг ёрлосон ёозгүй совин мэт байх ажээ. Өөрсөдтэй нь хүссэнээрээ харьцах харьцалтад минь захирагдах хүсэлгүйгээр бүх хүн тэнгэрт буй Дээд Эзэнд чимээгүйхэн залбирдаг. Гэвч бяцхан булгийн усны шоржигнох чимээ хүчит салхийг хааж яахан чадах билээ? Хүмүүсийн залбирлын чимээнээс болоод энэ нь гэнэтхэн зогсож яахан чадах билээ? Аянга ниргэн ид догшрон нижигнэхдээ хүний хулчгар занг бодон намжиж яахан болох билээ? Хүн салхинд хойш урагш ганхдаг; бороноос нуугдах гэж ийш тийшээ гүйдэг; Миний уур хилэнгийн дор хүмүүс дагжин чичирч, Намайг биед нь гараа хүргэнэ гэхээс ихэд айн, Би хүний цээж рүү цаг ямагт онилсон бууны ам мэт, мөн тэр Миний дайсан атлаа найз минь юм шиг л байдаг. Түүний төлөөх Миний жинхэнэ санаа зорилгыг хүн хэзээ ч олж илрүүлээгүй, Миний жинхэнэ зорилгыг хэзээ ч ойлгоогүй тул өөрийн мэдэлгүй Надад халддаг; өөрийн мэдэлгүй Намайг эсэргүүцдэг; тэгсэн атлаа санаандгүйгээр Миний хайрыг бас харсан. Уур хилэнгийн минь дундаас Миний царайг харна гэдэг хүний хувьд хэцүү. Би уур хилэнгийнхээ хар үүлсийн цаана нуугдаж, аянгын гялбаан дунд, бүхий л орчлон ертөнцийн дээр зогсон, Өөрийн өршөөлийг хүн рүү доош нь илгээдэг. Хүн Намайг мэддэггүй учраас Миний санаа зорилгыг ойлгож чадаагүйнх нь төлөө Би түүнийг гэсгээдэггүй. Хүмүүсийн нүдээр бол, Би уур хилэнгээ үе үе гаргаж, инээмсэглэлээ хараяа хараяа харуулдаг, гэхдээ хүн Намайг харлаа ч гэсэн Миний зан чанарыг бүхлээр нь хэзээ ч үнэхээр хараагүй бөгөөд хэтэрхий хөшүүн, мэдрэмжгүй болсон учраас эвэр бүрээний таатай чимээг сонсож мөн л чаддаггүй. Миний дүр хүний ой дурсамжид, Миний бие хаа бодолд нь оршдог мэт байдаг. Гэхдээ, хүмүүс өнөөг хүртэл хөгжсөн боловч Намайг үнэхээр харсан ганц ч хүн байгаагүй, учир нь хүний уураг тархи дэндүү ядмаг. Хүн Намайг “задлан шинжилсэн” хэдий ч түүний шинжлэх ухаан тун хангалтгүй хөгжсөн учраас шинжлэх ухааны судалгаа нь хараахан ямар ч үр дүнд хүрээгүй. Тиймээс “Миний дүрийн” тухай сэдэв үргэлж хов хоосон байж, гүйцээх хэн ч үгүй, дэлхийн дээд амжилтыг эвдэх хэн ч үгүй байсаар ирсэн, учир нь хүн төрөлхтөн эдүгээ бат зогсож чадна гэдэг ч асар золгүй явдлын дундах хэмжээлшгүй их тайтгарал ажээ.

1992 оны 3 дугаар сарын 23

24-Р БҮЛЭГ

Миний гэсгээлт бүх хүн дээр ирдэг мөртөө бүх хүнээс хол хэвээр байдаг. Хүн бүрийн бүхий л амьдрал Надад хандах хайр, үзэн ядалтаар дүүрсэн байдаг бөгөөд хэн ч хэзээ ч Намайг мэдээгүй—тиймээс Надад хандах хүний хандлага халуун, хүйтнээр үлээж, хэвийн байх чадваргүй байдаг. Гэсэн ч Би үргэлж хүнд санаа тавьж, хамгаалсаар ирсэн, харин өөрийн мулгуу байдлаас болж хүн Миний бүх үйл хэрэг болон ирмүүн санаа зорилгыг харах чадваргүй байдаг. Би бол бүх улс үндэстний дундах тэргүүлэгч Нэгэн, Би бол бүх хүний дундаас Хамгийн Дээд нь; зүгээр л хүн Намайг мэддэггүй. Маш олон жилийн турш Би хүмүүсийн дунд амьдарч, хүний ертөнц дэх амьдралыг мэдэрсэн атал тэр Намайг үргэлж үл ойшоож, Надтай харь гаригийн оршихуй мэт харьцсан. Зан чанар болон хэлний ялгаанаас болоод хүмүүс Надад гудамжны танихгүй хүн мэт ханддаг. Миний хувцас ч бас хэтэрхий өвөрмөц шинжтэй харагддаг, үүний үрээр хүнд Надтай харилцах итгэл дутдаг. Зөвхөн тэр үед л Би хүний ертөнцийн ганцаардлыг болон шударга бус байдлыг мэдэрдэг. Би бүгдийнх нь царайг ажиглан явган зорчигчдын дунд алхдаг. Тэд царайг нь уйтгар гунигаар дүүргэдэг өвчин туссан мэт байдаг; мөн өөрсдийнх нь чөлөөлөлтөд саад болдог гэсгээлтийн дунд амьдардаг мэт байдаг. Хүн өөрийгөө дөнгөлж, даруу төлөв дүр үзүүлдэг. Ихэнх хүмүүс Надаар өөрсдийгөө магтуулахын тулд Миний өмнө хуурамч дүр эсгэж, Миний тусламжийг олж авч магад болохоор Миний өмнө өөрсдийгөө зориуд өрөвдөлтэй болгон харагдуулдаг. Миний ар хударгаар хүмүүс бүгд Намайг аргалж, Надад дуулгаваргүй ханддаг. Миний зөв биш гэж үү? Энэ нь хүний амьд үлдэх бодлого биш гэж үү? Хэн амьдралдаа Намайг амьдран харуулсан бэ? Хэн бусдын дундаас Намайг өргөмжилсөн бэ? Хэн Сүнсний өмнө хүлээтэй байсан бэ? Хэн Сатаны өмнө Надад өгсөн гэрчлэлдээ бат зогссон бэ? Надад хандах “үнэнч” байдалдаа хэн үнэн зөв байдлыг нэмсэн бэ? Надаас болж хэн агуу улаан луунд хаягдсан бэ? Хүмүүс Сатантай хамт нүгэл үйлддэг, тэгээд одоо түүнтэй хамт шавар шавхайд хутгалддаг; тэд Намайг үл тоомсорлохдоо мэргэжилтэн, Намайг эсэргүүцэх эсэргүүцлийг зохион бүтээгчид бөгөөд Надтай хааш яаш хандахдаа “мэргэшсэн оюутнууд” юм. Өөрийн хувь тавилангийн төлөө хүн газар дээр энд тэндгүй хайдаг бөгөөд Би түүнийг даллан дуудах үед тэр Миний эрхэм нандин байдлыг мэдэрч чадахгүй хэвээр үлдэж, өөртөө найдах найдлагадаа үргэлжлүүлэн “итгэсээр”, бусдад “ачаа” болохыг хүсдэггүй. Хүний “хүсэл эрмэлзэл” эрхэм нандин мөртөө хэний ч хүсэл эрмэлзэл хэзээ ч онц дүн авч байгаагүй: Тэд бүгд Миний өмнө бутарч, ямар ч чимээ аниргүйгээр нуран унадаг.

Би өдөр болгон ярьж, өдөр бүр шинэ зүйл хийдэг. Хэрвээ хүн өөрийн бүх хүч чадлыг ашиглахгүй бол Миний дуу хоолойг сонсоход бэрхшээл үүсэж, Миний царайг харахад төвөгтэй болох болно. Хайртай хүн нь туйлын сайхан, дуу хоолой нь хамгийн эелдэг байж магадгүй боловч хүн Түүний алдар суутай царайг амархан

харж, дуу хоолойг нь сонсох чадваргүй. Эрин үеүдийн туршид хэн ч Миний царайг амархан харж байгаагүй. Би нэгэнтээ Петртэй ярьж, Паулд “харагдсан” боловч изриальчуудаас өөр хэн ч Миний царайг үнэхээр харж байгаагүй. Өнөөдөр Би хүнтэй хамт амьдрахын тулд хүмүүсийн дунд биечлэн ирсэн. Энэ нь та нарт үнэхээр ховор, эрхэм нандин санагдахгүй байна гэж үү? Та нар өөрсдийн цаг хугацааг хамгийн сайнаар ашиглахыг хүсэхгүй байна гэж үү? Ийм маягаар та нар цагийг дэмий өнгөрөөхийг хүсэж байна уу? Хүмүүсийн оюун ухаан дахь цагийн зүү гэнэт зогсоно гэж үү? Эсвэл цаг хугацаа эргээд ухарна гэж үү? Эсвэл хүн эргээд залуу болно гэжүү? Өнөөдрийн ерөөгдсөн амьдрал хэзээ нэгэн цагт дахин ирэх болов уу? Би “үргүй зарлагад” нь тохирсон “шагналыг” хүнд өгдөггүй. Би зүгээр л өөр бусад бүх зүйлийг даван гарч, Өөрийн ажлыг үргэлжлүүлэн хийдэг ба хүн завгүйгээс болж, эсвэл түүний хашхирах чимээнээс болж цаг хугацааны урсгалыг зогсоодоггүй. Хэдэн мянган жилийн туршид хэн ч Миний хүчийг хувааж чадаагүй бөгөөд хэн ч Миний анхдагч төлөвлөгөөг нурааж чадаагүй юм. Би орон зайг даван гарч, эрин үеийг дамнаж, бүх зүйлийн дээр болон дунд аль алинд нь Өөрийн бүхий л төлөвлөгөөний гол цөмийг эхлүүлэх болно. Хэдийгээр хүмүүс ам нээн эдгээр зүйлийн төлөө залбирч, бусад бүх зүйлийг умартан эдгээр зүйлийг Надаас шаарддаг боловч ганц ч хүн Надаас онцгой харьцаа хүртэж чадаагүй, эсвэл Миний гараас “шагнал” хүртэж чадаагүй. Энэ хүмүүсээс хэн нь ч, хэзээ ч Миний сэтгэлийг хөдөлгөөгүй бөгөөд Миний “цэвдэг хатуу” дуу хоолой тэднийг бүгдийг нь цааш түлхсэн юм. Ихэнх хүн өөрсдийгөө “хэтэрхий залуу” хэмээн бодсоор байдаг, иймээс хоёр дахь удаагаа өөрсдөд нь энэрэнгүй хандаж, асар их өршөөл үзүүлэхийг тэд Надаас хүлээдэг ба Би өөрсдийг нь арын хаалгаар оруулна гэж боддог. Гэсэн ч Би Өөрийнхөө төлөвлөгөөнд хөндлөнгөөс хааш яаш оролцож яаж болох юм бэ? Хүнийг газар дээр дахиад хэдэн жил амьдруулахын тулд залуу насных нь төлөө Би дэлхий эргэхийг зогсоож чадах уу? Хүний уураг тархи маш төвөгтэй мөртөө дутагддаг зүйлс бас байдаг юм шиг санагддаг. Үүний үр дүнд, хүний оюун санаанд Миний ажлыг зориуд тасалдуулах “гайхамшигтай аргууд” үргэлж гарч ирдэг.

Хэдийгээр Би хүний нүглийг олон удаа уучилж, сул доройгоос нь болж түүнд онцгой дэмжлэг үзүүлсэн боловч мэдлэггүй байдлаас нь болж Би түүнд зохих ёсоор хандсан цаг үе бас олон бий. Хүн ердөө л Миний сайхан сэтгэлд хэрхэн талархахаа хэзээ ч мэдэж байгаагүй, тийм болохоор тэр одоогийн нөхцөл байдалдаа живсэн байдаг: тоос шороонд хучигдсан, хувцас нь уранхай ноорхой, толгой дээрх үс нь хогийн ургамал мэт, нүүр нь хөө тортогтой, хөлөндөө балиар, өөрөө хийсэн гуталтай, гар нь яг л үхсэн бүргэдийн савар шиг хажуу талд нь сулхнаар унжиж байдаг. Намайг нүдээ нээгээд харахад хүн яг л ёроолгүй нүхнээс авираад гараад ирсэн юм шиг харагддаг. Би уурлахгүй байж чаддаггүй: Би хүнд үргэлж тэвчээртэй хандсаар ирсэн атал Миний ариун хаанчлалд хүссэнээрээ ирж, буцахыг Би яаж диаволд зөвшөөрч чадах билээ? Миний гэрт үнэгүй хоол идэхийг Би яаж гуйлгачинд зөвшөөрөх билээ? Тийм бохир чөтгөрийг Өөрийн гэрт зочноор хүлээн

авч Би яахан тэвчих билээ? Хүн үргэлж “өөртөө хатуу”, “бусдад зөөлөн” байсан атлаа Надад өчүүхэн төдий ч найрсаг хандаж байсан удаагүй, учир нь Би бол тэнгэр дэх Бурхан, иймээс тэр Надад өөрөөр ханддаг бөгөөд өчүүхэн ч болов хайр энэрлийг Надад хэзээ ч үзүүлж байгаагүй. Хүний нүд нэн сүйхээтэй мэт байдаг: Надтай тулгармагцаа түүний царай төрх тэр дороо өөрчлөгддөг ба хүйтэн, хайхрамжгүй царайдаа багахан ч гэсэн илэрхийлэл нэмдэг. Надад хандах хандлагаас нь болж Би хүнд тохирох хориг тогтоодоггүй, зүгээр л орчлон ертөнцийн дээрх тэнгэрийг харж, газар дээрх Өөрийн ажлыг гүйцэтгэдэг. Хүний ой ухаанд Би хэзээ ч ямар ч хүнд сайхан сэтгэл үзүүлээгүй, гэхдээ Би бас хэнд ч хэзээ ч зохисгүй хандаж байгаагүй. Хүн зүрх сэтгэлдээ Надад зориулсан “хоосон суудал” үлдээдэггүй учраас Намайг тэмүүлэн зүтгэж, түүний дотор оршиход тэр эрээ цээргүйгээр Намайг хүчлэн гаргаад, дараа нь долигонуур яриа, зусар үг ашиглан шалтаг тоочиж, өөрийгөө Миний таашаалын төлөө зориулахад хэтэрхий дутмаг агаад чадваргүй гэж хэлдэг. Түүнийг ярьж байхад царайд нь байнга “бараан үүл” хуралдаж, хүмүүсийн дунд юу юугүй гай гамшиг бууж ирэх гэж байгаа мэт байдаг. Тэгсэн ч тэр аюулыг үл хайхран Намайг яв гэж гуйсаар байдаг. Хэдийгээр Би хүнд Өөрийн үгийг, Өөрийн тэврэлтийн халуун дулааныг өгдөг ч тэр сонсох эрхтэнгүй мэт байдаг тул Миний дуу хоолойд өчүүхэн ч анхаарал хандуулдаггүй, оронд нь толгойгоо бариад яаруу сандруу гараад явдаг. Би бага зэрэг урам хугарч, бас бага зэрэг хилэгнэн хүнээс холддог. Харин тэгэхэд хүн тэр даруйдаа агуу шуурга, хүчирхэг давлагааны дайралт дунд нэн даруй алга болдог. Удалгүй тэр Над руу уйлан хашхирдаг, гэхдээ тэр яаж салхи, давлагааны хөдөлгөөнд нөлөөлж чадах билээ? Аажмаар хүний бүхий л ул мөр хаанаас ч олдохооргүйгээр алга болдог.

Эрин үеүдээс өмнө Би орчлон ертөнцийн дээрээс бүх газар нутгийг харсан. Би газар дээр агуу ажил төлөвлөсөн: Миний зүрх сэтгэлийн дагуу байдаг хүн төрөлхтнийг бүтээх, тэнгэр дээрхтэй адил газар дээрх хаанчлалыг бүтээн байгуулах, Миний хүч чадал тэнгэрийг бүрхэж, Миний мэргэн ухаан орчлон ертөнц даяар тархах боломж олгох. Иймээс олон мянган жилийн дараа, өнөөдөр Би Өөрийн төлөвлөгөөг үргэлжлүүлдэг. Гэвч газар дээрх Миний төлөвлөгөө буюу удирдлагыг хэн ч мэддэггүй, тэр ч бүү хэл газар дээрх Миний хаанчлалыг хардаггүй. Иймээс, хүн сүүдрийн хойноос хөөцөлддөг ба тэнгэр дэх Миний ерөөлийн төлөө “чимээгүй төлөөс” төлөхийг хүсэж, Намайг хуурахаар оролдон Миний өмнө ирдэг. Үр дүнд нь тэр Миний уур хилэнг өдөөж, Би түүнд шүүлт авчирдаг, гэсэн ч тэр сэрээгүй л байна. Тэр газар дээр байгаа зүйлийн талаар огтхон ч мэдэлгүй яг л газар доор ажиллаж байгаа мэт өөрийн хэтийн ирээдүйгээс өөр юуг ч эс хайдаг. Бүх хүний дундаас Миний гялалзах гэрлийн доор амьдарч байгаа хэн нэгнийг Би хэзээ ч хараагүй. Тэд харанхуйн ертөнцөд амьдардаг бөгөөд түнэр харанхуйдаа амьдарч дассан мэт санагддаг. Гэрэл гарч ирмэгц гэрэл ажилд нь саад болсон мэт тэд холддог; үүнээс болоод гэрэл тэдний амар тайван байдлыг алдагдуулж, тэднийг бөх унтах боломжгүй болгож орхисон мэт тэд бага зэрэг

унтууцсан харагддаг. Үр дүнд нь, хүн гэрлийг зайлуулахын тулд бүх хүчээ хуралдуулдаг. Гэрэл ч бас мэдрэмж дутмаг мэт байдаг тул хүнийг нойрноос нь сэрээдэг, харин хүн сэрэх үедээ нүдээ аньж, уур хилэнд автдаг. Тэр зарим талаар Намайг таашаадаггүй ч зүрх сэтгэлдээ Би оноог нь мэддэг. Би аажмаар гэрлийг эрчимжүүлж, бүх хүнийг Өөрийн гэрэл дунд амьдруулдаг, тийм болохоор тэд тун удалгүй гэрэлтэй харьцахдаа чадмаг болж, цаашлаад бүгд гэрлийг нандигнадаг. Энэ үед Миний хаанчлал хүмүүсийн дунд ирчихсэн, бүх хүн баяр хөөртэйгээр бүжиглэн тэмдэглэж, газар дэлхий гэнэт баяр хөөрөөр бялхдаг ба гэрэл ирснээр хэдэн мянган жилийн чимээгүй байдал эвдэгддэг…

1992 оны 3 дугаар сарын 26

25-Р БҮЛЭГ

Цаг хугацаа өнгөрч, нүд ирмэхийн төдийд өнөөдөр ирсэн. Миний Сүнсний удирдамж дор бүх хүн Миний гэрлийн дунд амьдардаг бөгөөд цаашид хэн ч өнгөрснийг боддоггүй, мөн өчигдөрт ч анхаарлаа хандуулдаггүй. Хэн өнөө үед амьдарч, оршин тогтнож байгаагүй вэ? Хэн хаанчлалд гайхалтай өдөр саруудыг өнгөрүүлээгүй вэ? Хэн нарны дор амьдраагүй вэ? Хэдийгээр хаанчлал хүмүүсийн дунд буучихсан ч үүний халуун дулааныг хэн ч үнэхээр туулаагүй; хүн үүний мөн чанарыг ойлголгүйгээр зүгээр л гаднаас нь авч үздэг. Миний хаанчлал бий болох үед үүнээс болж хэн баясан хөөрөхгүй байх юм бэ? Газар дээрх улс орнууд үнэхээр зугтаж чадна гэж үү? Агуу улаан луу заль мэхнийхээ ачаар үнэхээр зугтаж чадна гэж үү? Миний захиргааны зарлиг орчлон ертөнц даяар тунхаглагдаж, Миний эрх мэдлийг бүх хүний дунд тогтоож, сансар огторгуй даяар хэрэгжиж эхэлдэг; гэхдээ хүн үүнийг хэзээ ч үнэхээр мэдээгүй. Миний захиргааны зарлиг орчлон ертөнцөд илчлэгдэх үе нь бас газар дээрх Миний ажил бараг дуусах гэж байх үе юм. Би бүх хүний дунд ноёрхож, эрх мэдэл эзэмшиж байх үед, мөн Би бол цорын ганц Бурхан Өөрөө юм хэмээн танигдах үед Миний хаанчлал газар дээр бүрэн дүүрэн буух болно. Өнөөдөр бүх хүнд шинэ зам дээрх шинэ эхлэл байгаа. Тэд шинэ амьдрал эхлүүлсэн атал тэнгэрийнхтэй адил газар дээрх амьдралыг хэн ч, хэзээ ч үнэхээр туулаагүй. Та нар үнэхээр Миний гэрлийн дунд амьдардаг уу? Үнэхээр Миний үгэн дунд амьдардаг уу? Өөрсдийн хэтийн ирээдүйг боддоггүй хэн байна вэ? Өөрсдийн хувь заяанд түгшин зовдоггүй хэн байна вэ? Зовлон шаналлын далай дунд тэмцэлддэггүй хэн байна вэ? Өөрсдийгөө чөлөөлөхийг хүсдэггүй хэн байна вэ? Газар дээрх хүний шаргуу хөдөлмөрийн хариуд хаанчлалын ерөөлийг өгдөг үү? Хүний бүх хүсэл хүссэнээр нь биелж болно гэж үү? Би хаанчлалын үзэсгэлэнтэй сайхан дүр төрхийг хүний өмнө нэгэнтээ харуулсан, гэсэн ч тэр үүнийг ердөө шунахай нүдээр ширтсэн бөгөөд үүн рүү орохоор үнэхээр эрмэлзсэн хэн ч

байгаагүй. Би газар дээрх жинхэнэ нөхцөл байдлыг хүнд нэгэнтээ “мэдээлсэн”, гэвч тэр сонсохоос цаашгүй байсан ба Миний амнаас гарсан үгийг зүрх сэтгэлээрээ хүлээн аваагүй; Би тэнгэр дэх байдлыг хүнд нэгэнтээ хэлсэн, гэсэн ч тэр Миний үгийг гайхалтай үлгэр мэт үзээд, амаараа дүрсэлснийг минь чин сэтгэлээсээ хүлээн аваагүй. Өнөөдөр хаанчлалын дүр зураг хүмүүсийн дунд гялалздаг, гэвч хэн үүнийг хайн “өндөр уул, тал хөндийг туулсан” бэ? Би яруулаагүй бол хүн зүүднээсээ сэрээгүй хэвээр байх байсан. Газар дээрх амьдралдаа хүн үнэхээр сэтгэл татагддаг гэж үү? Хүний зүрх сэтгэлд үнэндээ ямар ч өндөр стандарт байхгүй гэж үү?

Миний ардууд хэмээн Надаар урьдчилан тогтоогдсон хүмүүс Надад өөрсдийгөө зориулж, Надтай эв зохицолтой амьдарч чаддаг. Миний нүдэнд тэд эрхэм нандин бөгөөд Миний хаанчлалд Намайг гэх хайраар гэрэлтэж байдаг. Өнөөдрийн хүмүүс дундаас хэн энэ нөхцөлийг биелүүлдэг вэ? Хэн Миний шаардлагуудад нийцэж чадах вэ? Миний шаардлагууд хүнд үнэхээр бэрхшээл учруулдаг гэж үү? Би зориуд хүнээр алдаа гаргуулдаг гэж үү? Би бүх хүнд хүлээцтэй хандаж, тэдэнд давуу эрх олгодог. Гэсэн ч энэ нь зөвхөн Хятад дахь Миний ардуудад хамаардаг. Би та нарыг дутуу үнэлдэг юм биш, мөн та нарыг хялайн хардаг ч юм биш, харин та нарт жинхэнэ, бодитоор хандаж байгаа юм. Хүмүүс гэр бүлдээ, эсвэл илүү өргөн хүрээний амьдралдаа аль алинд нь бүтэлгүйтэлтэй гарцаагүй тулгардаг. Гэсэн ч хэний зовлон зүдүүр өөрсдийнх нь гараар зохицуулагддаг вэ? Хүн Намайг мэдэх чадваргүй. Түүнд Миний гадаад төрхийн талаар зарим нэг ойлголт байдаг хэдий ч Миний мөн чанарыг мэддэггүй; тэр идэж буй хоолныхоо орцыг мэддэггүй. Хэн Миний зүрх сэтгэлийг анхааралтай ажиглаж чадах вэ? Хэн Миний өмнө Миний хүслийг үнэхээр ойлгож чадах вэ? Намайг газар дээр бууж ирэхэд харанхуй нөмөрсөн бөгөөд хүн “бөх унтаж” байдаг. Би газар сайгүй алхаж, урагдаж, ноорсон юм л хардаг ба харж тэвчихийн аргагүй байдаг. Хүн ердөө л зугаацаж цэнгэх дуртай бөгөөд “гадаад ертөнцийн зүйлсийг” анхаарах хүсэлгүй мэт байдаг. Бүх хүнд мэдэгдэлгүйгээр Би газар дэлхийг бүхэлд нь ажигладаг ч амиар дүүрсэн газар хаа ч байхгүйг хардаг. Тэр даруйдаа Би гэрэл болон дулаанаа илгээж, гурав дахь тэнгэрээс газар дэлхийг хардаг. Хэдийгээр гэрэл газарт тусаж, дулаан тархдаг ч зөвхөн гэрэл болон дулаан л баярлан хөөрч байгаа мэт санагддаг; тав тухтай наргиж буй хүмүүсийн доторх юуг ч тэдгээр нь өдөөдөггүй. Үүнийг хараад Би Өөрийн бэлтгэсэн “савааг” хүмүүсийн дунд нэн даруй хайрладаг. Саваа буухад гэрэл, дулаан аажмаар арилж, газар дэлхий нэн даруй эзгүй, харанхуй болдог—харанхуйгаас болоод зугаа цэнгэлээ үргэлжлүүлэх боломжийг хүн шүүрэн авдаг. Миний саваа ирж буй талаар хүн бүдэг бадагхан мэддэг боловч тэр хариу үйлдэл үзүүлдэггүй, “газар дээрх ерөөлөө” эдэлсээр байдаг. Дараа нь Миний ам бүх хүний гэсгээлтийг тунхагладаг бөгөөд орчлон ертөнц даяарх хүмүүс доош харан загалмайд цовдлогддог. Миний гэсгээлт ирэх үед уул нурах, газар хуваагдах дуу чимээ хүнийг чичрүүлж, дараа нь тэр цочин сэрдэг. Тэрээр цочирдож айгаад

зугтахыг хүсдэг ч аль хэдийн оройтсон байдаг. Миний гэсгээлт буухад Миний хаанчлал газар дээр буун ирж, бүх улс орон бут цохигдож, юу ч үлдээлгүйгээр, ул мөргүй алга болдог.

Өдөр бүр Би орчлон ертөнцийн байр байдлыг харж, өдөр бүр хүмүүсийн дунд Өөрийн шинэ ажлыг хийдэг. Гэсэн ч хүмүүс бүгд ажилдаа улайраад, хэн ч Миний ажлын хөгжил хөдөлгөөнд анхаарлаа хандуулдаггүй, эсвэл өөрсдөөс нь давсан зүйлсийн байр байдлыг анзаардаггүй. Хүмүүс өөрсдийн бүтээсэн шинэ тэнгэр, шинэ газарт амьдран, хэнийг ч хөндлөнгөөс оролцуулахыг хүсдэггүй мэт байдаг. Тэд бүгд өөрсдийгөө зугаацуулах ажил эрхэлж, “биеийн тамирын дасгалаа” хийнгээ өөрсдийгөө бахдан биширдэг. Хүний зүрх сэтгэлд Миний орон зай үнэхээр огт байхгүй гэж үү? Би үнэхээр хүний зүрх сэтгэлийн Захирагч байх чадваргүй гэж үү? Хүний сүнс үнэхээр түүнийг орхисон юм уу? Миний амнаас гарах үгийг хэн ер нь анхааралтай тунгаан бодсон бэ? Миний чин сэтгэлийн хүслийг хэн ер нь ухамсарласан бэ? Хүний зүрх сэтгэлийг үнэхээр өөр бусад зүйл эзэмдсэн юм гэж үү? Би хүн рүү олон удаа хашхирсан атал хэн нэгэн ер нь өрөвдөж байсан уу? Хүн чанартайгаар амьдарч байсан хүн ер нь байна уу? Хүн махан биетэй амьдардаг боловч хүн чанаргүй юм. Тэрээр амьтны ертөнцөд төрсөн гэж үү? Эсвэл тэр тэнгэрт төрж, бурханлаг чанарыг эзэмшсэн үү? Би хүнд Өөрийн шаардлагыг тавьдаг хэр нь тэрээр Миний үгийг ойлгодоггүй мэт, Би түүний хувьд ойртохын аргагүй мангас, харийн хүн мэт байдаг. Би хүнд маш олон удаа урам хугарсан, түүний муу гүйцэтгэлээс болж Би маш олон удаа уурлан хилэгнэсэн, түүний сул доройгоос болж Би маш олон удаа цөхөрсөн. Яагаад Би хүний зүрх сэтгэл дэх сүнслэг мэдрэмжийг сэргээж чаддаггүй юм бэ? Яагаад Би хүний зүрх сэтгэл дэх хайрыг өдөөж чаддаггүй юм бэ? Хүн яагаад Намайг нүдний цэцгий шигээ үзэхийг хүсдэггүй юм бэ? Хүний зүрх сэтгэл өөрийнх нь биш гэж үү? Түүний сүнсэнд өөр зарим зүйл байраа эзэлсэн үү? Яагаад хүн тасралтгүй уйлан гасалдаг юм бэ? Яагаад тэр өрөвдмөөр байдаг юм бэ? Уй гашуутай байх үедээ тэр яагаад Миний оршин тогтнолыг үл тоодог юм бэ? Би түүнийг сүлбэсэн юм гэж үү? Би санаатайгаар түүнийг хаясан юм гэж үү?

Миний нүдэнд хүн бол бүх зүйлийн захирагч юм. Би түүнд багагүй хэмжээний эрх мэдэл өгч, газар дээрх бүх зүйл, уулан дээрх өвс ургамал, ой модон доторх амьтад, усан дахь загас зэргийг хүнээр удирдуулсан. Гэсэн ч үүнд баярлахын оронд хүн түгшүүрт автсан. Түүний бүхий л амьдрал шаналгаатай, яарч сандарсан, хоосон байдалд зугаа цэнгэл нэмсэн зүйл болсон; түүний бүхий л амьдралд ямар ч шинэ ололт, бүтээл байдаггүй. Хэн ч энэ хоосон хөндий амьдралаас ангижирч чадахгүй, хэн ч, хэзээ ч амьдралын утга учрыг олж илрүүлээгүй, хэн ч, хэзээ ч жинхэнэ амьдралыг туулаагүй. Хэдийгээр өнөөгийн хүмүүс бүгд Миний цацарсан гэрэл дор амьдардаг ч тэнгэр дэх амьдралын талаар юу ч мэдэхгүй. Хэрвээ Би хүнд өршөөнгүй хандахгүй, хүн төрөлхтнийг аврахгүй бол бүх хүн дэмий ирж, газар дээрх амьдрал нь утга учиргүй болох ба бахархах зүйл юу ч үгүйгээр дэмий явж

одох болно. Бүх шашин, нийгмийн хүрээ, улс үндэстэн, шашны урсгал бүрийн хүмүүс бүгдээрээ газар дээрх хоосон байдлыг мэднэ, тэд бүгдээрээ Намайг эрж хайж, Намайг эргэн ирэхийг хүлээдэг—гэсэн ч Намайг ирэх үед хэн Намайг танин мэдэх чадвартай вэ? Би бүх зүйлийг бий болгосон, Би хүн төрөлхтнийг бүтээсэн, өнөөдөр Би хүмүүсийн дунд бууж ирсэн. Гэвч хүн Намайг няцааж, Надаас өшөө авдаг. Хүн дээр Миний хийдэг ажил түүнд ашиг тусгүй байдаг гэж үү? Би үнэхээр хүнийг сэтгэл хангалуун байлгах чадваргүй юм гэж үү? Яагаад хүн Намайг голдог вэ? Яагаад хүн Надад маш хүйтэн хөндий, хайхрамжгүй ханддаг вэ? Газар дэлхий яагаад цогцоор бүрхэгдсэн бэ? Хүний төлөө Миний бүтээсэн ертөнцийн байдал үнэхээр энэ гэж үү? Би хүнд юутай ч харьцуулшгүй баялгийг өгсөн байхад тэр яагаад Надад хариуд нь хоосон гараа өгдөг вэ? Яагаад хүн Намайг үнэхээр хайрладаггүй вэ? Тэр яагаад хэзээ ч Миний өмнө ирдэггүй вэ? Миний бүх үг үнэхээр хий дэмий байсан юм гэж үү? Миний үг усны уур шиг алга болсон юм гэж үү? Хүн яагаад Надтай хамтран ажиллах дургүй байдаг юм бэ? Миний өдөр ирэх нь үнэхээр хүний үхэх мөч гэж үү? Миний хаанчлал бий болох үед Би үнэхээр хүнийг устгах юм гэж үү? Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний туршид яагаад хэн ч, хэзээ ч Миний хүслийг ойлгож байгаагүй вэ? Миний амнаас гарсан айлдваруудыг нандигнахын оронд хүн яагаад тэдгээрийг зэвүүцэж, голдог вэ? Би хэнийг ч ялладаггүй, харин зүгээр л бүх хүнийг тайвшруулж, өөрсдийгөө эргэцүүлэх ажил хийхэд хүргэдэг.

1992 оны 3 дугаар сарын 27

ХҮМҮҮС ЭЭ, БҮГД БАЯРЛАН ХӨӨРЦГӨӨ!

Миний гэрэлд хүмүүс гэрлийг дахин хардаг. Миний үгээс хүмүүс таашаадаг зүйлсээ олдог. Би Зүүн зүгээс ирсэн, Би Зүүн зүгээс гаралтай. Миний суу алдар цацрахад бүх үндэстэн гэрэлтэж, бүгд гэрэлд гарч, харанхуйд нэг ч зүйл үлддэггүй. Хаанчлалд, Бурханы ардууд Бурхантай хамт амьдардаг амьдрал хэмжээлшгүй жаргалтай. Хүмүүсийн ерөөлт амьдралд ус баяртайгаар бүжиж, Миний элбэг дэлбэг байдлыг уулс хүмүүстэй хамт эдэлдэг. Миний хаанчлалд бүх хүн чармайж, шаргуу ажиллаж, үнэнч гэдгээ харуулж байна. Хаанчлалд бослого, эсэргүүцэл гэж байхгүй болж, тэнгэр газар хоёр бие биедээ найдаж, хүн бид хоёр бие биедээ түшиглэн, амьдралын баярт цэнгэлээр дамжуулан гүн мэдрэмжээр дотносдог… Энэ цаг үед Би тэнгэр дэх амьдралаа албан ёсоор эхэлдэг. Сатаны үймээн байхаа больж, хүмүүс амралтад ордог. Орчлон даяар, хүмүүс дунд амьдарч буй хүмүүсийн хувиар бус, Бурхантай хамт амьдарч буй хүмүүсийн хувиар Миний сонгосон хүмүүс энгүй их ерөөгдөж, Миний суу алдар дотор амьдардаг. Бүх хүн төрөлхтөн Сатаны завхралыг туулж, амьдралын жаргал зовлонг тултал нь амссан. Одоо Миний

гэрэлд амьдарч байгаа хүн баясахаас өөр яалтай? Энэ сайхан мөчөөс татгалзаж, алдаж өнгөрүүлж яахан чадах билээ? Хүмүүс ээ! Миний төлөө зүрх сэтгэлдээ дуу дуулж, баяртайгаар бүжицгээ! Чин сэтгэлээ аваад Надад өргөн барьцгаа! Миний төлөө бөмбөрөө дэлдэж, баяртайгаар тоглоцгоо! Би баяр баяслаа бүх орчлон даяар цацруулдаг! Хүмүүст Би алдар суут царайгаа илчилдэг! Би чанга дуугаар уриалан дуудна! Би орчлон ертөнцийг давна! Би угаасаа хүмүүсийн дунд хаанчилдаг! Хүмүүс Намайг өргөмжилдөг! Би дээд хөх тэнгэрт хөвж, хүмүүс Надтай хамт алхдаг. Би хүмүүсийн дунд алхаж, Миний ардууд Намайг тойрон хүрээлдэг! Хүмүүсийн зүрх сэтгэл баярлаж, дуу хуур нь орчлонг донсолгож, тэнгэрт ан цав үүсгэдэг! Орчлон ертөнц манан буданд бүрхэгдсэн байхаа больж, шалбааггүй болж, муу ус цуглахаа больдог. Орчлонгийн ариун хүмүүс ээ! Миний шинжилт дор та нар жинхэнэ дүр төрхөө харуулдаг. Та нар бузар булайд бүрхэгдсэн хүмүүс бус, хаш чулуу шиг цэвэр ариун хүмүүс, бүгд Миний хайртууд, бүгд Миний баяр хөөр билээ! Бүх зүйл эргэн амилдаг! Ариун хүмүүс бүгд халуун тэврэлтэд минь орж, мэгшин уйлах, санаа зовохоо больж, өөрсдийгөө Надад өргөж, гэрт минь эргэн ирж, тэнгэрт Надад үйлчлэхээр эргэн ирсэн бөгөөд тэд төрөлх нутагтаа Намайг зогсолтгүй хайрлана! Үүрд мөнхөд үл өөрчлөгдөнө! Уй гуниг хаа байна! Нулимс хаа байна! Махан бие хаа байна! Газар дэлхий улиран оддог ч тэнгэр үүрд. Би бүх ард түмэнд үзэгдэж, бүх ард түмэн Намайг магтдаг. Балар эрт үеэс цаг хугацааны төгсгөл хүртэл энэ амьдрал, энэ гоо үзэсгэлэн өөрчлөгдөхгүй. Хаанчлалын амьдрал энэ билээ.

26-Р БҮЛЭГ

Хэн Миний гэрт амьдран суусан бэ? Хэн Миний төлөө зогссон бэ? Хэн Миний оронд зовсон бэ? Хэн Миний өмнө ам өчгөө өгсөн бэ? Хэн өнөөг хүртэл Намайг дагасан хэр нь хайхрамжгүй болоогүй вэ? Яагаад хүмүүс бүгдээрээ хүйтэн хөндий, хатуу сэтгэлтэй байдаг юм бэ? Хүн төрөлхтөн яагаад Намайг орхисон бэ? Хүмүүс яагаад Надаас залхсан бэ? Хүний ертөнцөд яагаад халуун дулаан байдал байдаггүй юм бэ? Сионд байхдаа Би тэнгэрт байдаг халуун дулааныг амталж, тэнгэрт байдаг ерөөлийг эдэлсэн. Дахин хүн төрөлхтний дунд амьдраад Би хүний ертөнцийн гашуун зовлонг амсаж, хүмүүсийн дунд байдаг янз бүрийн байр байдлыг бүгдийг нь Өөрийн нүдээр харсан. Нэг л мэдэхэд, Намайг “өөрчлөгдөхийн” хэрээр хүн өөрчлөгдсөн, гагцхүү ийм маягаар л тэр өнөөдөртэй золгожээ. Миний төлөө юу ч хийж чаддаг бай гэж Би хүнээс шаарддаггүй, Миний төлөө ямар нэгэн өсөлт гарга гэж ч шаарддаггүй. Харин Миний төлөвлөгөөний дагуу үйлдэж, Надад дуулгаваргүй хандахгүйгээр, эсвэл Миний ичгүүрийн тэмдэг бололгүйгээр Надад цангинасан гэрчлэл хийж чаддаг байгаасай гэж л Би хүсдэг. Хүмүүсийн дунд Надад сайн гэрчлэл хийж, Миний нэрийг алдаршуулсан хүмүүс байсан ч хүний хэрэгжүүлэлт,

биеэ авч явах байдал Миний сэтгэлийг хангалуун болгож яахан чадах билээ? Хүн Миний хүсэлд нийцэж, Миний хүслийг биелүүлж яахан чадах билээ? Газар дээрх уул ус, газар дээрх цэцэг ногоо, өвс ургамал, модод бүгд Миний гарын урыг харуулж, бүгд Миний нэрийн төлөө оршин тогтнодог. Гэтэл хүн яагаад Миний шаардсан стандартад хүрч чаддаггүй юм бэ? Адгийн дорд байдлаасаа болоод тэр үү? Би түүнийг өргөмжилснөөс болоод тэр үү? Хүнд Би хэт харгис хандсанаас болоод тэр үү? Хүн яагаад Миний шаардлагаас цаг ямагт айна вэ? Өнөөдөр хаанчлал дахь олон түмний дундаас та нар дуу хоолойг минь л сонсохоос биш, царайг минь харахыг яагаад хүсдэггүй юм бэ? Миний үгийг Миний Сүнстэй тааруулалгүйгээр яагаад зүгээр л хардаг юм бэ? Яагаад Намайг дээд тэнгэр, доод газарт тусгаарладаг юм бэ? Газар дээр байхдаа Би тэнгэрт байдгаасаа өөр байдаг гэж үү? Тэнгэрт байхдаа Би газарт буун ирж чадахгүй гэж үү? Газарт байхдаа Би тэнгэрт хүрэх үнэ цэнгүй байдаг юм гэж үү? Газарт байх үедээ Би дорд амьтан мэт, тэнгэрт байх үедээ Би өргөмжит оршихуй мэт, тэнгэр газрын дунд эвлэршгүй ан цав байгаа мэт байдаг. Гэвч хүний ертөнцийнхөн эдгээр зүйлийн гарал үүслийн талаар юу ч мэдэхгүй мэт байцгаан, Миний үг дуу чимээнээс цаашгүй, ямар ч утга учиргүй мэтээр үргэлж Миний эсрэг явж ирлээ. Бүх хүн төрөлхтөн Миний үгэнд хичээл зүтгэл гаргаж, гадаад байдлыг минь өөрсдөө шинжилдэг ч бүгд л бүтэлгүйтэж, хичээл чармайлт нь ямар ч үр дүнд хүрдэггүй, харин ч Миний үгэнд цохигдоод дахин босож зүрхэлдэггүй.

Хүн төрөлхтний итгэлийг турших үед минь нэг ч хүн жинхэнэ гэрчлэл хийж чаддаггүй, нэг ч хүн бүхнээ өргөн барьж чаддаггүй; харин зүрх сэтгэлээ Надад булаалгах гэж байгаа мэт хүн үргэлжлүүлэн нуугдаад, сэтгэлээ нээхээс татгалзсаар байдаг. Иов хүртэл шалгалтын үеэр хэзээ ч үнэхээр тууштай зогсоогүй, мөн зовлон шаналал дунд ч сайн сайхныг цацруулаагүй. Хавар цагийн дулаанд бүх хүн ялимгүй ногоордог; өвлийн хүйтэн жаварт тэд хэзээ ч ногооноороо байдаггүй. Яс арьс болж, турж эцсэн биеийн хэмжээтэй хүн Миний санаа зорилгыг биелүүлж чадахгүй. Бүх хүний дунд бусдадаа үлгэр дуурайл болж чадах нэг ч хүн байхгүй, учир нь бүх хүн үндсэндээ адилхан, нэг нэгээсээ ямар ч ялгаагүй, өөр хоорондоо ялгарах зүйл багатай. Иймээс хүмүүс өнөөдөр ч гэсэн Миний үйл хэргийг бүрэн дүүрэн мэдэх чадваргүй хэвээр байдаг. Миний гэсгээлт бүх хүн төрөлхтөн дээр буух үед л хүмүүс өөрийн мэдэлгүй Миний ажлыг мэддэг болно, мөн Намайг юу ч хийгээгүй, хэнийг ч албадаагүй байхад хүн Намайг мэдэж авч, улмаар Миний үйл хэргийг харна. Энэ бол Миний төлөвлөгөө, Миний харуулсан үйл хэргийн нэг тал бөгөөд хүний мэдэх ёстой зүйл юм. Хаанчлалд тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл дахин сэргэж, амийн хүчээ ахин дахин олж авч эхэлдэг. Газар дэлхийн байр байдал өөрчлөгдсөний улмаас нутаг дэвсгэрийн хил хязгаар ч бас өөрчлөгдөж эхэлдэг. Өмнө нь Би, газар нь газраас тасарч, газар нь газартай нэгдэх үе бол бүх улс үндэстнийг бут цохих үе минь байх болно гэж зөгнөсөн. Энэ үед Би бүх бүтээлийг шинэчлэн бүхий л орчлон ертөнцийг дахин хуваарилж, улмаар орчлон ертөнцийг

эмх цэгцэд оруулж, хуучныг шинэ болгон хувиргана—энэ бол Миний төлөвлөгөө, эдгээр нь Миний ажил билээ. Дэлхийн улс үндэстэн, ард түмэн бүгд Миний сэнтийн өмнө буцаж ирэх үед Би тэнгэрийн бүх хишгийг аваад хүний ертөнцөд хүртээнэ, ингэснээр хүний ертөнц Миний ачаар зүйрлэшгүй их хишгээр бялхах болно. Гэхдээ хуучин ертөнц оршсоор байгаа цагт Би Өөрийн уур хилэнг улс үндэстнүүд рүү нь буулгаж, захиргааны зарлигаа орчлон ертөнц даяар ил тод зарлаж, түүнийг зөрчсөн хэнд ч гэсгээлт хүртээнэ:

Намайг үг хэлэхээр орчлон ертөнцийн зүг царайгаа хандуулахад бүх хүн төрөлхтөн Миний дуу хоолойг сонсож, дараа нь орчлон ертөнц даяар Миний хийсэн бүх үйл хэргийг хардаг. Миний хүслийн эсрэг явдаг хүмүүс буюу хүний үйл хэргээр Намайг эсэргүүцдэг хүмүүс Миний гэсгээлт дор унана. Би тэнгэр дэх тоймгүй олон одыг авч шинэчилнэ, Миний ачаар нар сар ч шинэчлэгдэнэ—хурмаст тэнгэр урьдынх шигээ байхаа больж, газар дээрх тоо томшгүй олон зүйл шинэчлэгдэнэ. Миний үгээр дамжуулан бүх зүйл бүрэн төгс болно. Орчлон ертөнц дэх олон улс үндэстэн шинээр хуваагдаж, Миний хаанчлалаар солигдоно, ийнхүү газар дээрх улс орнууд үүрд үгүй болж, бүгдээрээ Надад шүтэн мөргөдөг хаанчлал болно; газар дээрх бүх улс орон сөнөж, оршин тогтнохоо болино. Орчлон ертөнц дэх хүмүүсээс диаволд харьяалагддаг бүх хүн устана; Сатаныг шүтдэг бүх хүн Миний дүрэлзсэн галд унана. Өөрөөр хэлбэл, одоо энэ урсгалд байгаа хүмүүсээс бусад нь үнсэн товрог болно. Олон ард түмнийг гэсгээх үед минь шашны ертөнц дэх хүмүүс цагаан үүл хөлөглөн айсуй Ариун Нэгнийг харсан байх тул Миний ажлаар байлдан дагуулагдаж, өөр өөр түвшинд Миний хаанчлалд эргэн ирнэ. Бүх хүн төрлөөрөө ангилагдаж, өөрсдийнхөө үйлдэлд тохирсон гэсгээлтийг хүртэнэ. Миний эсрэг зогссон хүмүүс бүгд мөхнө; харин газар дээрх үйл хэрэг нь Надтай хамаагүй байсан хүмүүс биеэ хэрхэн авч явснаасаа үүдэн Миний хөвгүүд, Миний ардуудын засаглал дор газар дэлхий дээр оршсоор байна. Би тоо томшгүй олон хүн, тоймгүй олон улс үндэстэнд Өөрийгөө илчилж, газар дэлхий дээр Өөрийнхөө дуу хоолойгоор үг хэлж, агуу ажлынхаа биелэлтийг тунхаглан, бүх хүн төрөлхтөн үүнийг нүдээрээ харна.

Дуу хоолой минь эрчимжихэд Би орчлон ертөнцийн байр байдлыг ч бас ажигладаг. Тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл бүгд Миний үгээр шинэчлэгддэг. Тэнгэр өөрчлөгдөж, газар ч бас өөрчлөгддөг. Хүмүүсийн анхдагч төрх ил болж, аажмаар хүн бүр төрлийнхөө дагуу ангилагдаж, өөрийн мэдэлгүй гэр бүлийнхнийхээ тэвэрт буцан очих замаа олно. Үүнийг Би ихэд таална. Би саад тотгороос ангид бөгөөд нэг л мэдэхэд Миний агуу ажил гүйцэлдэж, тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл бүгд өөрчлөгддөг. Би дэлхийг бүтээхдээ бүх зүйлийг төрлөөр нь загварчилж, хэлбэр дүрстэй бүх зүйлийг өөрсдийнх нь төрөлтэй хамт тавьсан. Миний удирдлагын төлөвлөгөөний төгсгөл ойртож байгаа тул Би бүтээлийн хуучин байр байдлыг сэргээнэ; Би бүх зүйлийг анхдагч байдалд нь оруулж, бүхнийг гүн гүнзгий өөрчилнө, ингэснээр бүх зүйл Миний төлөвлөгөөнд эргэж ирнэ. Цаг нь ирлээ! Миний төлөвлөгөөний сүүлчийн үе шат гүйцэлдэх гэж байна. Аяа, бузар хуучин

ертөнц өө! Чи Миний үгийн дор гарцаагүй унана! Миний төлөвлөгөөгөөр юу ч үгүй болох нь гарцаагүй! Аяа, тоо томшгүй олон бүтээгдсэн зүйл ээ! Та нар бүгд Миний үгэн дотроос шинэ амь олж авна—захирагч Эзэнтэй болно! Аяа, цэвэр ариун, өө сэвгүй шинэ ертөнц өө! Миний алдар дотор чи гарцаагүй сэргэнэ! Аяа, Сион Уул аа! Чимээгүй байхаа боль—Би ялгууснаар эргэж ирлээ! Бүтээлийн дундаас Би бүх газар дэлхийг шинждэг. Газар дээр хүн төрөлхтөн шинэ амьдрал эхлүүлж, шинэ итгэл найдвартай болсон. Аяа, Миний ардууд аа! Миний гэрэл дотор та нар эргэн амилахгүй байж яаж чадах юм бэ? Миний удирдамж дор баярлан дэвхцэхгүй байж яаж чадах юм бэ? Хуурай газар баясан хашхирч, ус хөгжөөнтэйгөөр инээн долгилно! Аяа, дахин амилсан Израиль аа! Миний урьдчилан тогтоосныг чи бахдахгүй байж яаж чадах юм бэ? Хэн мэгшин уйлсан бэ? Хэн цурхиран уйлсан бэ? Хуучны Израиль үгүй болж, өнөөгийн Израиль дэлхий дээр өндийн, сүндэрлэн байгуулагдаж, бүх хүний зүрх сэтгэлд бослоо. Өнөөдрийн Израиль Миний ардуудаар дамжуулан оршин тогтнолын эх үүсвэрт гарцаагүй хүрнэ! Аяа, заналт Египет ээ! Чи Миний эсрэг зогсохоо больсон байлгүй дээ? Чи Миний өршөөлийг далимдуулж, Миний гэсгээлтээс зугтахыг оролдож яаж чадна вэ? Миний гэсгээлт дотор оршихгүй байж яаж чадах юм бэ? Миний хайрладаг бүх хүн гарцаагүй үүрд мөнх амьдарна, харин Миний эсрэг зогсдог бүхнийг Би мөнхөд гэсгээх нь гарцаагүй. Учир нь Би хартай Бурхан бөгөөд хийсэн бүхнийх нь төлөө хүмүүсийг амархан хэлтрүүлэхгүй. Би бүхий л газар дэлхийг ажиглан харж, зөвт байдал, сүр жавхлан, уур хилэн болон гэсгээлттэйгээр ертөнцийн зүүн зүгт гарч ирж, тоймгүй олон хүнд Өөрийгөө илчилнэ!

1992 оны 3 дугаар сарын 29

27-Р БҮЛЭГ

Хүний үйлдэл хэзээ ч Миний зүрх сэтгэлийг хөдөлгөж байгаагүй, Надад хэзээ ч эрхэм нандин гэж санагдаж байгаагүй. Хүний нүдээр бол Би түүнд үргэлж хатуу чанга хандаж, эрх мэдлээ үргэлж түүн дээр хэрэгжүүлж байгаа. Хүний бүх үйлдэлд Миний төлөө хийдэг зүйл бараг үгүй, мөн Миний нүдний өмнө бат зогсдог зүйл бараг үгүй. Эцсийн эцэст хүний бүх зүйл Миний өмнө чимээгүй нуран унадаг; дараа нь л Би Өөрийн үйлдлийг харуулж, бүтэлгүйтлээр нь дамжуулан хүн бүрд Өөрийгөө мэдүүлдэг. Хүний уг чанар өөрчлөгдөлгүй үлддэг. Тэдний зүрх сэтгэлд байгаа зүйл Миний хүслийн дагуу байдаггүй—энэ нь Надад хэрэгтэй зүйл биш. Миний хамгийн их жигшдэг зүйл бол хүний өөрчлөгдөшгүй байдал ба хуучнаа давтах явдал боловч Намайг мэдэхдээ үргэлжлүүлэн бүтэлгүйтэж, Намайг үргэлж хол байлгаж, Миний өмнө хүслийн минь дагуу хэзээ ч үйлдэхгүй, харин нүдэн далдуур Намайг эсэргүүцэхэд хүмүүсийг хүргэдэг хүч юу вэ? Тэдний үнэнч байдал уу? Намайг

хайрладаг тэдний хайр уу? Тэд яагаад гэмшиж, шинэ хүн болж чаддаггүй юм бэ? Хүмүүс шавар шавхайгүй газар амьдрахын оронд намаг балчиг дотор амьдрахыг яагаад үргэлж хүсдэг юм бэ? Би тэдэнд зохисгүй хандсан юм гэж үү? Би тэднийг буруу зүг рүү чиглүүлсэн юм гэж үү? Би тэднийг там руу хөтөлж байгаа юм гэж үү? Хүн бүр “там”-д амьдрахад бэлэн байдаг. Тэдний доторх бүх зүйл тамаас ирдэг тул гэрэл ирэхэд нүд нь даруй сохордог. Гэвч хүмүүс үүнийг мэддэггүй, зүгээр л эдгээр “тамын ерөөл”-ийг эдэлдэг. Тэр ч бүү хэл, Би эдгээр эрдэнэсийг нь булаан аваад, өөрсдийг нь “оршин тогтнох үндэсгүй” болгож орхино гэж айсандаа тэд эдгээрийгээ үнэт эрдэнэ мэт цээжиндээ тас тэвэрч байдаг. Хүмүүс Надаас эмээдэг, тийм ч учраас Намайг газар дээр ирэхэд Надаас хол байж, Надад ойртохыг үзэн яддаг, учир нь тэд “өөрсдөдөө төвөг удахыг” хүсдэггүй, харин ч “газар дээрх аз жаргалыг” эдлэхийн тулд гэр бүлийнхээ доторх эв зохицлыг хэвээр хадгалахыг хүсдэг. Гэхдээ, Би гагцхүү хүний гэр бүлийг устгахаар энд ирсэн учир хүмүүст хүссэнээ хийхийг нь зөвшөөрч чадахгүй. Намайг хүрэлцэн ирэх мөчөөс эхлээд тэдний гэр бүлийн амар амгалан байдал арилдаг. Би хүний гэр бүлийг бүү хэл, бүх үндэстнийг бут цохихоор зорьдог. Хэн Миний атгаас зугтаж чадах билээ? Ерөөл хүлээн авдаг хүмүүс хүсээгүйнхээ ачаар зугтаж магадгүй юм гэж үү? Гэсгээлт амсдаг хүмүүс айдсынхаа ачаар Миний өрөвдөх сэтгэлийг хүлээн авч магадгүй юм гэж үү? Миний бүх үгээс хүмүүс Миний хүсэл болон үйлдлийг харсан, гэхдээ хэн ер нь бодол санааныхаа хүлээсээс ангижирч чадах билээ? Миний үгэн дотроос, эсвэл Миний үггүйгээр хэн ер нь өөр замыг олж чадах билээ?

Хүн Миний халуун дулааныг мэдэрч, Надад чин сэтгэлээсээ үйлчилсэн бөгөөд Миний өмнө чин сэтгэлээсээ захирагдаж, бүхнийг Миний төлөө, Миний өмнө хийсэн. Гэвч өнөөдөр хүмүүс үүнд хүрч чаддаггүй; тэд өлсгөлөн чононд бариулсан мэт сүнсээрээ л уйлдаг бөгөөд арга мөхөстөн Намайг харж, тасралтгүйгээр Над руу хашхирдаг. Гэвч эцэст нь тэд бэрхшээлээсээ зугтаж чаддаггүй. Урьд нь хүмүүс Миний өмнө амлалт өгч, Миний сайхан сэтгэлийг хайраараа хариулахын тулд тэнгэр, газраар тангараглаж байсныг Би санаж байна. Тэд Миний өмнө гашуудан уйлсан ба тэдний уйлах чимээ сэтгэл шимшрэм, тэвчихүйеэ бэрх байв. Би шийдвэрээс нь үүдэн хүмүүст үргэлж тусалдаг байлаа. Тоо томшгүй удаа хүмүүс Надад захирагдахаар Миний өмнө ирж, хайр татам төрх нь мартахын аргагүй байсан. Тоо томшгүй олон удаа тэд тууштай үнэнчээр Намайг хайрлаж, чин сэтгэл нь биширмээр байв. Тоо томшгүй олон удаа тэд амиа золиослох хэмжээнд Намайг хайрлаж, Намайг өөрсдөөсөө илүү хайрласан—чин сэтгэлийг нь хараад Би тэдний хайрыг хүлээн авсан юм. Тоо томшгүй олон удаа тэд үхэлтэй нүүр тулахаа үл хайхран Миний өмнө, Миний төлөө өөрсдийгөө өргөн барьсан ба Би тэдний нүүр царайнаас санаа зовнилыг нь арилгаж, дүр төрхийг нь анхааралтайгаар дэнсэлж үзсэн. Би тэднийг нандин эрдэнэс мэт хайрлаж байсан удаа тоо томшгүй олон, мөн тэднийг Өөрийн дайсан мэт үзэн ядаж байсан удаа ч тоймгүй олон. Гэсэн ч Миний оюун санаанд юу байгааг хүн ухан ойлгох аргагүй хэвээр байдаг. Хүмүүсийг

гуниглах үед Би тайвшруулахаар ирдэг, сул дорой байх үед нь тэдэнд туслахаар ирдэг. Тэднийг төөрөх үед Би тэдэнд зүг чиг өгдөг. Тэднийг уйлах үед Би нулимсыг нь арчдаг. Гэвч Намайг гуниглах үед хэн чин сэтгэлээсээ тайтгаруулж чадах билээ? Намайг туйлын их зовниж байх үед хэн Миний мэдрэмжийг анхаардаг билээ? Намайг гашуудах үед сэтгэлийн минь шархыг хэн анагааж чадах билээ? Надад хэн нэгэн хэрэгтэй байх үед хэн сайн дураараа Надтай хамтран ажилладаг билээ? Хүмүүсийн Надад хандаж байсан урьдын хандлага одоо гээгдээд, дахин хэзээ ч ирэхгүй юм гэж үү? Тэдний ой ухаанд яагаад юу ч үлддэггүй юм бэ? Хүмүүс яаж энэ бүх зүйлийг мартаж орхив оо? Хүн төрөлхтнийг дайсан нь завхруулснаас энэ бүхэн болоогүй гэж үү?

Тэнгэрэлчүүд Намайг магтан хөгжим тоглох үедээ хүнийг өрөвдөх сэтгэлийг минь өөрийн эрхгүй өдөөдөг. Миний зүрх сэтгэл даруй гунигаар дүүрч, энэхүү зовлонт сэтгэл хөдлөлөөс Өөрийгөө салгах боломжгүй байдаг. Хүнээс хагацаж, дараа нь эргэн нийлэхийн баяр хөөр, уйтгар гунигтаа бид хуучин мэдрэмжээ дурсаж чаддаггүй. Дээд тэнгэр, доод газарт тусгаарлагдсан хүн бид хоёрын уулзаж чадах цаг хугацаа ховорхон. Хэн урьдын мэдрэмжүүдээ санагалзахаас ангижирч чадах билээ? Өнгөрсний талаар дурсан санахаа хэн больж чадах билээ? Урьдын мэдрэмжүүдийг үргэлжлүүлэхээр найддаггүй хэн байх билээ? Миний эргэн ирэхийг хүсэмжилдэггүй хэн байх билээ? Хүнтэй эргэн нэгдэхийг минь хүсэн хүлээдэггүй хэн байх билээ? Миний зүрх сэтгэл гүнээ түгшиж, хүний сүнс ихэд санаа зовдог. Сүнсээрээ адилхан хэдий ч бид үргэлж хамтдаа байж, бие биеэ дандаа хараад байж чаддаггүй. Тиймээс бүх хүн төрөлхтний амьдрал уй гунигаар дүүрэн, эрч хүчээр дутмаг байдаг, учир нь хүн үргэлж Намайг хүсэн эрмэлзэж байсан билээ. Хүмүүс тэнгэрээс цохигдон унасан зүйлс мэт байсан; тэд газар дэлхий дээрээс Миний нэрийг дуудан хашхирч, газраас харцаа өргөн Над руу хардаг—гэвч тэд яаж ховдог чонын амнаас зугтаж чадах билээ? Тэд үүний заналхийлэл, уруу таталтаас өөрсдийгөө чөлөөлж яаж чадах билээ? Хүмүүс Миний төлөвлөгөөний зохицуулалтад дуулгавартай байдгаасаа болоод өөрсдийгөө золиослохгүй байж яаж чадах билээ? Тэднийг чангаар гуйх үед Би тэднээс нүүр буруулаад, цааш нь харж тэвчдэггүй; гэсэн ч тэдний уйлааныг Би яаж сонсохгүй байж чадах билээ? Би хүний ертөнцийн шударга бус явдлыг засна. Би дэлхий даяар Өөрийнхөө ажлыг гардан хийнэ, ардуудыг минь дахин хорлохыг Сатанд зөвшөөрөхгүй, хүссэн бүхнээ дахин хийхийг дайснууддаа зөвшөөрөхгүй. Би газар дээр Хаан болж, Өөрийн сэнтийг тэнд шилжүүлээд, бүх дайснаа газар унаган мөргүүлж, тэдний нүглийг Өөрийн өмнө улайлгана. Уйтгар гунигтай минь уур холилдон, Би орчлон ертөнцийг бяц дэвсэж, хэнийг ч өршөөхгүйгээр, дайснуудынхаа зүрх сэтгэлд айдас хуруулна. Би газар дэлхийг тэр чигт нь үнсэн товрог болгож, дайснуудаа сүйрэлд унагана, тийнхүү үүнээс хойш тэд хүн төрөлхтнийг завхруулахаа болих юм. Миний төлөвлөгөө хэдийнээ тогтоогдсон бөгөөд хэн ч үүнийг өөрчлөх ёсгүй. Намайг орчлон ертөнц дээгүүр сүр жавхлантайгаар

хэрэн явахад бүх хүн шинэ болж, бүх зүйл амь орно. Хүн уйлахаа больж, Надаас тусламж гуйн хашхирахаа болино. Тэгэхэд Миний зүрх сэтгэл баярлан хөөрч, хүмүүс баяр хөөрөө тэмдэглэн Над руу ирнэ. Орчлон ертөнц тэр аяараа дээрээсээ доош хүртэл хөөрөн баясна…

Өнөөдөр Би дэлхийн улс үндэстнүүд дунд Өөрийн биелүүлэхээр зорьсон ажлыг хийж байна. Би хүн төрөлхтний дунд явж, Өөрийн төлөвлөгөөн дэх бүх ажлыг хийдэг бөгөөд бүх хүн Миний хүслийн дагуу янз бүрийн улс орнуудыг хагалан бутаргаж байна. Тэр өдөр үнэндээ ойртож, тэнгэрэлчүүд бүрээгээ дуугаргаж байгаа учраас газар дэлхий дээрх хүмүүс өөрсдийн хүрэх газарт анхаарлаа хандуулдаг. Цаашид ямар ч саатал байхгүй, үүнээс болоод бүх бүтээл баяр хөөртэйгөөр бүжиглэж эхэлнэ. Хэн Миний өдрийг хүссэнээрээ уртасгаж чадах юм бэ? Дэлхийн хүн үү? Эсвэл тэнгэр дэх одод уу? Эсвэл тэнгэрэлчүүд үү? Израилийн ард түмний авралыг эхлүүлэхээр айлдвараа айлдах үед Миний өдөр бүх хүн төрөлхтөнд тулан ирдэг. Хүн бүр Израилийг эргэн ирэхээс эмээдэг. Израиль эргэн ирэх үед тэр нь Миний алдрын өдөр байх тул энэ нь бас бүх зүйл өөрчлөгдөн шинэчлэгдэх өдөр байх болно. Зөвт шүүлт бүхий л орчлон ертөнцөд ойртон ирэх үед хүний ертөнц зөвт байдлын талаар сонсож байгаагүй учраас бүх хүн зүрхшээн айдаг. Зөвт байдлын Нар гарч ирэх үедээ Зүүн зүгийг гэрэлтүүлж, дараа нь орчлон ертөнцийг тэр аяар нь гэрэлтүүлэн, хүн бүрд хүрнэ. Хэрвээ хүн үнэхээр Миний зөвт байдлыг үйлддэг бол айх зүйл юу байх юм бэ? Миний ардууд бүгд Миний өдөр хүрэлцэн ирэхийг хүлээдэг, тэд бүгд Миний өдөр ирэхийг хүсэн хүлээдэг. Зөвт байдлын Нар гэх үүргээрээ бүх хүн төрөлхтөнд залхаан цээрлүүлэлт авчирч, хүн төрөлхтний хүрэх газрыг зохицуулахыг минь тэд хүлээдэг. Миний хаанчлал бүх орчлон ертөнцийн дээр хэлбэржиж байгаа ба Миний сэнтий хэдэн зуун сая хүний зүрх сэтгэлд ноёрхдог. Тэнгэрэлчүүдийн тусламжтайгаар Миний агуу үйл удахгүй үр дүнд хүрнэ. Миний хөвгүүд болон ардууд бүгд эргэн ирэхийг минь тэсэн ядан хүлээж, хэзээ ч дахин салахгүйгээр Надтай эргэн нэгдэхээр хүсэн тэмүүлдэг. Миний хаанчлалын үй олон ард түмэн өөрсөдтэй нь хамт байгааг минь баяртайгаар тэмдэглэн, бие бие рүүгээ гүйлдэхгүй байж яаж чадах билээ? Энэ нь ямар ч төлөөс төлөх хэрэггүй нэгдэл юм гэж үү? Би бүх хүний нүдэнд хүндтэй бөгөөд бүгдийнх нь үг Намайг тунхагладаг. Түүнчлэн, Би эргэн ирэх үедээ дайсны бүх хүчийг байлдан дагуулна. Цаг нь ирсэн! Би хүмүүсийн дунд Өөрийн ажлыг өрнүүлж, хүмүүсийн дунд Хаан болон хаанчилна! Би эргэж ирэхийн даваан дээр байна! Мөн Би явах гэж байна! Энэ бол хүн бүрийн найдаж буй зүйл, тэдний хүсдэг зүйл билээ. Миний өдөр ирэхийг Би бүх хүнд харуулна, тэд бүгдээрээ Миний өдөр ирэхийг баяр хөөртэйгөөр угтана!

1992 оны 4 дүгээр сарын 2

28-Р БҮЛЭГ

Сионоос ирэхэд бүх зүйл Намайг хүлээж байсан, Сионд буцаж очиход бүх хүн Надтай мэндэлсэн. Намайг ирж, очих үед Надад дайсагнадаг зүйлс Миний алхамд хэзээ ч саад болоогүй, иймээс Миний ажил түүртэх юмгүй дэвшсэн. Өнөөдөр бүх бүтээлийн дунд ирэхэд минь Намайг дахиад яваад өгөх вий, тэгэхээр дэмжлэг болгон түшиж тулдаг зүйлээ алдах вий гэж ихэд айсан бүх зүйл Надтай дуугүйхэн мэндчилдэг. Бүх зүйл Миний удирдамжийг дагаж, Миний гарын заасан чиглэлийг аждаг. Амнаас минь гарсан үг олон бүтээлийг төгс болгож, дуулгаваргүй олон хөвгүүнийг гэсгээлээ. Ийнхүү бүх хүн Миний үгийг анхааралтай харж, амнаас минь гарах айлдварыг чих тавин чагнадаг бөгөөд энэ сайхан боломжийг алдахаас маш их айдаг. Ийм учраас Би үгээ үргэлжлүүлэн хэлсэн, ингэснээр Миний ажил илүү хурдан гүйцэлдэж, газар дээр тааламжтай нөхцөл хурдан бүрдэж, газар дээрх эзгүйрлийн дүр зургийг засаж залруулна. Тэнгэр өөд харах үедээ Би хүн төрөлхтөнтэй нүүр учрахаар дахин эргэдэг; бүх газар нутаг тэр дороо амьдралаар дүүрч, агаарт тоос хөвөхөө больж, газрыг лаг шавар бүрхэхээ байдаг. Хоёр нүд минь даруй гэрэл цацруулсны үрээр газар газрын хүмүүс Намайг хүндлэн, Надад хоргоддог. Өнөөгийн дэлхийн хүмүүсээс—Миний гэрт байгаа бүх хүнийг оролцуулаад—хэн нь үнэхээр Надад хоргоддог вэ? Төлсөн төлөөсний минь хариуд хэн зүрх сэтгэлээ өгдөг вэ? Миний гэрт хэн ер нь амар амгалан оршин суусан бэ? Миний өмнө хэн ер нь өөрсдийгөө үнэхээр өргөн барьсан бэ? Намайг шаардлага тавихад хүн “жижигхэн агуулахаа” даруйхан хаадаг. Намайг юм өгөхөд хүн, эд баялгийг минь сэмхэн авах гээд даруйхан амаа ангайдаг бөгөөд Надад цохиулна гэж ихэд эмээн зүрх сэтгэлдээ ямагт дагжин чичирдэг. Иймд хүний ам хагас дутуу ангайсан байдаг бөгөөд Миний хайрладаг эд баялгийг үнэнхүү эдлэх чадваргүй. Хүнийг Би амархан ялладаггүй атал хүн ямагт гараас минь зулгаан, өөрт нь өршөөл үзүүлэхийг гуйдаг; гуйж гувших үед нь л Би “өршөөл” дахин үзүүлж, амнаас минь гарах хамгийн хатуу үгийг өгдөг бөгөөд үүнд хүн даруй ичиж, “өршөөлийг” минь шууд хүртэх чадваргүй болчхоод харин бусдаар дамжуулан авдаг. Бүх үгийг минь бүрэн ухаарсан үед хүний биеийн хэмжээ хүсэлд минь нийцэж, гуйлт нь хий дэмий, хэрэггүй биш, харин үр өгөөжтэй байдаг; хүн төрөлхтний хуурамч бус, чин сэтгэлийн гуйлтыг Би ерөөдөг.

Би үе үеийн туршид үйлдэж, үг хэлж ирсэн боловч өнөөдөр Миний хэлдэг шиг айлдварыг хүн хэзээ ч сонсож байгаагүй, мөн Миний сүр жавхлан, шүүлтийг хүн хэзээ ч амсаж байгаагүй юм. Хэдийгээр дээр үед зарим хүн Миний тухай домог сонссон ч эд баялгийн минь цараг үнэндээ хэн ч олж илрүүлж байсан удаагүй. Өнөөгийн хүмүүс амнаас минь гарах үгийг сонсдог ч Миний аманд хэчнээн олон нууц байгааг мэдэхгүй хэвээр тул амыг минь элбэг дэлбэгийн ундарга гэж тооцдог. Бүх хүн Миний амнаас ямар нэгэн зүйл олж авахыг хүсдэг. Төрийн нууц ч юм уу, тэнгэрийн оньсого, эсвэл сүнсний ертөнцийн орчил, хүн төрөлхтний хүрэх газар гэх

мэт зүйлийг бүх хүн хүлээн авах хүсэлтэй. Иймээс Би хүмүүсийг цуглуулж, “үлгэр” ярьж өгье гэсэн бол ярихыг минь сонсохын тулд тэд “хэвтрээсээ” даруйхан босож ирэх байлаа. Хүмүүс хэтэрхий дутуу дулимаг: хүнд “нэмэлт шим тэжээл” шаардлагатайгаас гадна “сэтгэлийн дэм”, “сүнслэг хангамж” хэрэгтэй. Бүх хүн үүгээр дутагддаг; бүх хүн ийм “өвчтэй”. Илүү сайн үр дүнд хүрч, тэднийг эрүүл энх болгож, эдгээсний минь ачаар тэд хэвийн байдалдаа эргэн орно байх гэсэндээ Би хүний өвчнийг анагаадаг. Агуу улаан лууг та нар үнэхээр үзэн яддаг гэж үү? Үнэхээр, чин сэтгэлээсээ үзэн яддаг уу? Яагаад Би та нараас ийм олон удаа асуув? Би энэ асуултыг яагаад ахин дахин асуугаад байна вэ? Та нарын сэтгэлд агуу улаан лууны ямар дүр зураг байдаг вэ? Үүнийг үнэхээр зайлуулсан уу? Түүнийг үнэхээр эцгээ гэж үздэггүй юу? Асуултад минь байгаа санаа зорилгыг бүх хүн ухаарах ёстой. Энэ нь хүмүүсийн уурыг хүргэх, хүмүүсийн дунд үймээн дэгдээх, хүний гарах замыг өөрөөр нь олуулахын төлөө бус, харин агуу улаан лууны хүлээснээс чөлөөлөгдөх боломжийг бүх хүнд олгохын төлөө байдаг. Гэвч хэн ч санаа зовох учиргүй. Бүхнийг Би үгээрээ гүйцэлдүүлнэ; Миний гүйцэтгэх ажилд ямар ч хүн оролцож болохгүй, үүнийг ямар ч хүн хийж чадахгүй. Би бүх газрын агаарыг арчин цэвэрлэж, чөтгөрүүдийн бүх ул мөрийг газар дэлхий дээрээс үгүй хийнэ. Би аль хэдийн эхэллээ, агуу улаан луу орогнодог газарт Би гэсгээлтийн ажлынхаа эхний алхмыг эхлүүлнэ. Ийнхүү Миний гэсгээлт бүхий л орчлонд буусан гэдгийг, мөн Би бүх газрыг хардаг тул агуу улаан луу, элдэв янзын бузар сүнс гэсгээлтээс минь зайлахад хүчин мөхөстөнө гэдгийг харж болно. Газар дээрх Миний ажил дуусаж, өөрөөр хэлбэл шүүлтийн эрин үе эцэслэхэд агуу улаан лууг Би албан ёсоор гэсгээнэ. Миний ардууд агуу улаан лууг зөвт байдлаар гэсгээхийг минь харж, зөвт байдлаас минь үүдэн магтаал урсгаж, зөвт байдлаас минь үүдэн ариун нэрийг минь үүрд шагших нь лавтай. Одоогоос та нар үүргээ албан ёсоор гүйцэтгэж, газар даяар Намайг албан ёсоор үүрдийн үүрд магтана!

Шүүлтийн эрин үе оргилдоо хүрэхэд Би ажлаа дуусгах гэж яарахын оронд гэсгээлтийн эрин үеийн нотолгоонд үүнийгээ нэгтгэж, энэ нотолгоог Өөрийн бүх ардад харуулна; үүнээс илүү их үр өгөөж гарна. Энэ нотолгоо бол агуу улаан лууг гэсгээдэг Миний арга хэрэгсэл бөгөөд Би ардууддаа үүнийг өөрсдийнх нь нүдээр үзүүлж, улмаар тэд Миний зан чанарыг илүү сайн мэднэ. Агуу улаан луу гэсгээгдсэн цагт ардууд минь Намайг эдэлдэг. Агуу улаан лууны эсрэг хүмүүсийг нь босгож, бослого хийлгэх нь Миний төлөвлөгөө бөгөөд ардуудаа төгс болгодог Миний арга, мөн бүх ард маань амиа өсгөх сайхан боломж энэ юм. Гэрэлт саран мандахад шөнийн нам гүм байдал даруй эвдэгддэг. Сар навсгар ноорхой ч хүний сэтгэл санаа сайхан байж, сарны гэрэл туссан үзэсгэлэнт дүр зургийг бахдан сарны гэрэлд тайван сууна. Хүн сэтгэл хөдлөлөө дүрсэлж үл чадна; хүн бодлоо өнгөрсөн үе рүү буцаахыг хүсэх шиг, ирээдүйг урьдчилан харахыг хүсэх шиг, одоо цагт баясаж байгаа ч юм шиг болдог. Нүүрэнд нь инээмсэглэл тодорч, таатайхан агаарт сэнгэнэсэн үнэр түгнэ; сэвшээ салхи үлээж эхлэх зуур хүн хурц үнэр анхилахыг

мэдэрч, үүнд согтох шиг болж, сэрж чаддаггүй. Энэ үед л би хүмүүсийн дунд биечлэн ирсэн бөгөөд хүн хурц анхилуун үнэрийг илүү мэдэрдэг ба ийнхүү бүх хүн энэ анхилуун үнэр дунд амьдардаг. Би хүнтэй эв найртай байдаг бөгөөд хүн Надтай эвсэг амьдарч, Намайг гажууд үзэхээ больдог, хүний дутагдлыг Би засахаа больж, хүний царайд зовнисон төрх үзэгдэхээ больж, бүхий л хүн төрөлхтнийг үхэл заналхийлэхээ больдог. Өнөөдөр би гэсгээлтийн эрин үе рүү хүнтэй хамт дэвшин, түүнтэй мөр зэрэгцэн урагшилдаг. Би ажлаа хийж байна, өөрөөр хэлбэл, саваагаараа хүмүүсийн дунд цохиж, хүний тэрслүү байдал дээр саваагаа буулгадаг. Хүний үзэхэд, Миний саваа гойд хүч агуулсан мэт байдаг: Миний бүх дайсан дээр саваа минь бууж, тэднийг амархан өршөөдөггүй; Намайг эсэргүүцдэг бүх хүний дунд саваа анхдагч чиг үүргээ гүйцэтгэдэг; Миний гар дахь бүх хүн санаа зорилгын минь дагуу үүргээ гүйцэтгэдэг бөгөөд хүслийг минь тэд хэзээ ч үл ойшоогоогүй, мөн чанараа тэд хэзээ ч өөрчлөөгүй. Иймээс ус шуугьж, уул нурж, их мөрөн сарниж, хүн ямагт өөрчлөлтөд орж, нар бүүдийж, сар харанхуйлж, хүн амар амгалан амьдрах өдөр хоноггүй болж, газар дээр тайван байх цаг дуусаж, тэнгэр дахин хэзээ ч тайван, нам гүм байхаа больж, оршин тогтнохоо байна. Бүх зүйл шинэчлэгдэж, анхдагч төрхөө олно. Газар дээрх бүх айл өрх тарж бутран, дэлхий дээрх бүх улс үндэстэн задран хуваагдана; эхнэр нөхөр хоёр дахин уулзах өдөргүй болж, ээж хүү хоёр дахин үл уулзаж, эцэг охин хоёрын уулзалт дахин хэзээ ч үл тохионо. Газар дэлхий дээр байсан бүхнийг Би бут цохино. Би сэтгэл хөдлөлгүй тул хүмүүст сэтгэл хөдлөлөө илэрхийлэх боломж олгодоггүй бөгөөд хүмүүсийн сэтгэл хөдлөлийг туйлын их жигших болсон юм. Хүн хоорондын сэтгэл хөдлөлөөс болж Би нэг тийш хаягдан, улмаар тэдний нүдэнд “өрөөл бусад” болсон; хүн хоорондын сэтгэл хөдлөлөөс болж Би мартагдсан; хүн сэтгэл хөдлөлөөсөө үүдэн “мөс чанараа” авах боломжийг ашигладаг; хүн сэтгэл хөдлөлөөсөө л үүдэн Миний гэсгээлтээс үргэлж залхдаг; хүн сэтгэл хөдлөлийнхөө л улмаас Намайг шударга бус, ёс бус гэж дуудан, аливааг зохицуулахдаа хүний сэтгэлийг тоохгүй байна гэцгээдэг. Газар дээр Надад бас төрөл садан бий гэж үү? Бүхий л удирдлагын төлөвлөгөөнийхөө төлөө хэн Над шиг өдөр шөнөгүй нойр хоолоо хасан ажилласан юм бэ? Хүнийг Бурхантай харьцуулж яаж болох юм бэ? Хүн Бурхантай нийцтэй байж яаж чадах вэ? Бүтээгч Бурхан бүтээгдсэн хүнтэй яаж нэг төрлийнх байж болох билээ? Газар дээр Би үргэлж хүнтэй хамт амьдарч, үйлдэж яаж чадах билээ? Миний зүрх сэтгэлийн төлөө хэн зовниж чаддаг юм бэ? Хүний залбирал уу? Нэгэнтээ Би хүнтэй нэгдэж, хамт алхахыг зөвшөөрсөн—бас хүн өнөөг хүртэл Миний халамж, хамгаалалтад амьдарч ирсэн, гэхдээ хүнд ер нь Миний халамжаас гарч чадах өдөр ирнэ гэж үү? Хүн Миний зүрх сэтгэлийн төлөө хэзээ ч зовнилд автаж байгаагүй боловч гэрэлгүй газар нутагт амьдраад байж хэн чадах юм бэ? Миний ерөөлийн ачаар л хүн өнөөдрийг хүртэл амьдарч ирсэн билээ.

1992 оны 4 дүгээр сарын 4

29-Р БҮЛЭГ

Бүх зүйл дахин амилсан өдөр Би хүмүүсийн дунд ирсэн ба Би түүнтэй хамт гайхалтай өдөр, шөнүүдийг өнгөрүүлсэн. Зөвхөн энэ үед л хүн Миний ойр дотно байдлыг жаахан мэдэрдэг ба Надтай харилцах нь улам байнгын болох тусам тэрээр Надад юу байгаа, Би юу болох талаар зарим нэгийг ойлгодог—үүний үр дүнд тэр Миний талаар тодорхой хэмжээний мэдлэг олж авдаг. Бүх хүний дунд Би толгойгоо өргөж харахад тэд бүгд Намайг хардаг. Гэсэн ч дэлхийд гай гамшиг тохиолдох үед тэд тэр даруй зовон түгшиж, Миний дүр төрх тэдний зүрх сэтгэлээс арилдаг; гамшиг ирэхэд тэд балмагдаж, Миний сургамжийг үл ойшоодог. Би хүмүүсийн дунд олон жилийг өнгөрүүлсэн боловч хүн дандаа тоомжиргүй хэвээр байж, Намайг ер мэдээгүй. Өнөөдөр Би хүнтэй Өөрийн амаар ярьж, Өөрөөсөө ямар нэг зүйл авхуулахын тулд бүх хүнийг өмнөө ирүүлдэг ч тэд Надаас зай барьсан хэвээр байгаа тул Намайг мэддэггүй. Миний мөр орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаар хүртэл явах үед хүн өөрийгөө эргэцүүлж эхлэх ба бүх хүн Над руу ирж, Миний өмнө мэхийн ёсолж, Намайг шүтэн мөргөнө. Энэ нь Би алдрыг олж авах өдөр, Миний эргэн ирсэн өдөр, мөн Миний явах өдөр байх болно. Одоо Би бүх хүн төрөлхтний дунд Өөрийн ажлыг эхэлчихсэн, бүх орчлон даяар Өөрийн удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийг албан ёсоор эхлүүлчихсэн. Анхаарал болгоомжгүй хэнд ч энэ мөчөөс эхлэн хайр найргүй гэсгээлт оногдож болзошгүй бөгөөд энэ нь хэдийд ч тохиолдож магадгүй. Би цэвдэг сэтгэлтэйдээ энэ биш; харин ч энэ нь Миний удирдлагын төлөвлөгөөний нэг алхам; бүгд Миний төлөвлөгөөний алхмуудын дагуу явах ёстой ба ямар ч хүн үүнийг өөрчилж чадахгүй. Намайг ажлаа албан ёсоор эхлэх үед бүх хүн Намайг хөдлөхөд хөдөлж, тийнхүү орчлон ертөнц даяарх хүмүүс өөрсдөө Миний алхамтай хөл нийлүүлж, орчлон ертөнц дахинд “баяр баясал” бий болох ба хүн Надаас урам зориг авна. Үүний үр дүнд агуу улаан луу өөрөө Надад шавхуурдуулан будилж, самуурсан байдалд орж, Миний ажилд үйлчлэх ба хэдий дургүй байсан ч өөрийн хүслийг дагаж чадалгүй, Надад захирагдахаас өөр ямар ч аргагүй болно. Миний бүхий л төлөвлөгөөнд агуу улаан луу бол Миний товойлгогч, Миний дайсан, түүнчлэн Миний зарц; тиймээс Би тэрэнд тавих Өөрийн “шаардлагуудыг” хэзээ ч сулруулаагүй. Тийм учраас бие махбодтой болсон Миний ажлын сүүлчийн шат тэрний гэрт гүйцэлддэг. Ийм маягаар агуу улаан луу Миний төлөө зохистойгоор үйлчлэл үзүүлж илүү сайн чадна, үүгээр Би агуу улаан лууг байлдан дагуулж, Өөрийн төлөвлөгөөг гүйцээнэ. Намайг ажиллаж байхад тэнгэрэлчүүд бүгд Надтай хамт шийдвэрлэх тулаан эхлүүлж, сүүлчийн шатанд Миний хүслийг биелүүлэхээр шийддэг, ингээд газар дээрх хүмүүс тэнгэрэлчүүдийн адилаар Миний өмнө буулт хийж, Намайг эсэргүүцэх ямар ч хүсэлгүй болж, Миний эсрэг тэрслэх юу ч хийдэггүй. Эдгээр нь орчлон ертөнц даяарх Миний ажлын чиг хандлага билээ.

Хүмүүсийн дунд Миний ирсэн зорилго болон ач холбогдол нь бүх хүн төрөлхтнийг аварч, бүх хүн төрөлхтнийг Өөрийнхөө гэрт буцааж авчран тэнгэрийг

газартай дахин нэгтгэж, мөн хүнийг тэнгэр, газрын хооронд “дохио” дамжуулдаг болгох явдал, учир нь энэ бол хүний төрөлхийн чиг үүрэг билээ. Хүн төрөлхтнийг бүтээх үедээ Би бүх зүйлийг тэдэнд бэлдэж хийсэн ба дараа нь Миний шаардлагын дагуу өөрсдөд нь өгсөн баялгийг хүлээн авахыг хүн төрөлхтөнд зөвшөөрсөн. Тиймээс Миний удирдамж дор хүн төрөлхтөн өнөөдөртэй золгосон гэж Би хэлдэг. Энэ нь бүгд Миний төлөвлөгөө юм. Бүх хүн төрөлхтний дотор тоо томшгүй олон хүн Миний хайрын хамгаалалт дор оршин суудаг, бас тоо томшгүй олон хүн Миний үзэн ядалтын гэсгээлт дор амьдардаг. Хүмүүс бүгдээрээ Надад залбирдаг ч өнөөгийн нөхцөл байдлаа өөрчилж чадахгүй л байдаг; найдвараа алдахаар тэд жам ёсонд захирагдахаас аргагүй болж, Надад дуулгаваргүй хандахаа больж чаддаг, учир нь хүний гүйцэтгэж чадах юм энэ л юм. Хүний амьдралын байдлын тухайд гэвэл, хүн жинхэнэ амьдралыг хараахан олоогүй, тэрээр энэ хорвоогийн шударга бус байдал, ганцрал гутрал, золгүй байдлыг ухаарч хараахан чадаагүй—тиймээс, хэрэв гай зовлон гараагүй бол ихэнх хүмүүс мөн л Байгаль Эхийг шүтэх байсан ба өөрсдийнхөө “амьдралын” амтанд татагдсаар байх байсан. Энэ нь хүний ертөнцийн бодит байдал биш гэж үү? Хүнд хэлж буй Миний авралын дуу хоолой энэ биш гэж үү? Яагаад хүн төрөлхтний дотроос нэг нь ч Намайг хэзээ ч үнэхээр хайрлаж байгаагүй вэ? Хүн яагаад зөвхөн гэсгээлт, шалгалтын дунд байхдаа л Намайг хайрладаг мөртөө Миний хамгаалалт дор байхдаа хэн ч Намайг хайрладаггүй юм бэ? Би Өөрийн гэсгээлтийг хүн төрөлхтөнд олон удаа хүртээсэн. Тэд үүнийг хардаг боловч дараа нь үл ойшоодог, тэгээд тэд үүнийг тухайн үедээ судалж, цэгнэдэггүй, иймээс хүнд очдог бүхэн бол ердөө л хайр найргүй шүүлт юм. Энэ бол Миний ажиллах аргуудын зөвхөн нэг нь боловч энэ нь мөн л хүнийг өөрчилж, хүнээр Өөрийгөө хайрлуулахын тулд байдаг билээ.

Би хаанчлалд хаанчилдаг, цаашлаад Би бүхий л орчлон ертөнцөд хаанчилдаг; Би бол хаанчлалын Хаан, орчлонгийн Тэргүүний аль аль нь билээ. Энэ цагаас эхлээд Би сонгогдоогүй бүх хүнийг цуглуулж, Өөрийн ажлыг Харь үндэстний дотор эхлэх болно, мөн Би Өөрийн захиргааны зарлигийг бүхий л ертөнцөд зарлаж, ингэснээр Өөрийн ажлын дараагийн алхмыг амжилттай эхлүүлнэ. Би Өөрийн ажлыг Харь үндэстнүүдийн дунд түгээхийн тулд гэсгээлт ашиглана, өөрөөр хэлбэл, Би Харь үндэстнүүдийн эсрэг хүч хэрэглэнэ. Мэдээжээр, энэхүү ажил нь сонгогдсон хүмүүсийн дунд явагдах Миний ажилтай зэрэг хийгдэнэ. Миний ардууд газар дээр засаглаж, эрх мэдэл эзэмших үе нь бас газар дээрх бүх хүнийг байлдан дагуулсан өдөр байх бөгөөд цаашлаад энэ нь Миний амрах цаг байна—зөвхөн тэр үед л Би байлдан дагуулагдсан бүхэнд харагдана. Би ариун хаанчлалд харагдаж, бузар газар нутгаас Өөрийгөө нууна. Байлдан дагуулагдсан, Миний өмнө дуулгавартай болсон бүх хүн Миний царайг нүдээрээ харж, Миний дуу хоолойг чихээрээ сонсож чадна. Энэ бол эцсийн өдрүүдэд төрсөн хүмүүсийн ерөөл, энэ бол Миний урьдчилан тогтоосон ерөөл бөгөөд үүнийг ямар ч хүн өөрчилж чадахгүй. Ирээдүйн ажлын төлөө өнөөдөр Би ингэж ажилладаг. Миний бүх ажил хоорондоо хамааралтай,

бүгдэд нь дуудлага ба хариу байдаг: Ямар ч алхмыг хэзээ ч гэнэт зогсоодоггүй, хэзээ ч ямар ч алхмыг бусдаас нь тусад нь гүйцэтгэдэггүй. Ийм биш гэж үү? Өнгөрсөн үеийн ажил өнөөдрийн ажлын суурь биш гэж үү? Өнгөрсөн үеийн үг өнөөдрийн үгийн анхдагч биш гэж үү? Өнгөрсөн үеийн алхмууд өнөөдрийн алхмын эхлэл биш гэж үү? Би хуйлмал номыг албан ёсоор нээх үе нь орчлон ертөнц даяарх хүмүүс гэсгээгдэх үе, дэлхий дахины хүмүүст шалгалт тулгарах үе бөгөөд энэ нь Миний ажлын оргил үе юм; бүх хүн гэрэл гэгээгүй газар амьдарч, бүх хүн хүрээлэн буй орчныхоо заналхийлэл дунд амьдардаг. Өөрөөр хэлбэл, бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөг хүртэл хүмүүсийн туулаагүй амьдрал энэ бөгөөд эрин үеүдийн турш хэн ч ийм амьдралыг “эдэлж” байгаагүй, иймээс Би өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийсэн гэж хэлж байгаа юм. Энэ нь хэрэг явдлын бодит байдал бөгөөд энэ нь дотоод утга учир билээ. Миний өдөр бүх хүн төрөлхтөнд ойртож байгаа учраас, мөн энэ нь хол юм шиг харагдахгүй, харин яг хүний нүдний өмнө байгаа учраас хэн айхгүй байж чадах юм бэ? Бас хэн үүнд баярлахгүй байж чадах юм бэ? Бузар Вавилон хотын төгсгөл эцэстээ ирлээ; хүн цоо шинэ дэлхийтэй дахин учирч, тэнгэр, газар өөрчлөгдөн шинэчлэгдсэн.

Намайг бүх улс үндэстэн, бүх хүнд илрэн харагдах үед тэнгэрт цагаан үүлс хөврөн Намайг далдална. Мөн газар дээрх шувууд Миний төлөө баяртайгаар дуулан бүжиглэж, газар дээрх уур амьсгалыг онцлон тэмдэглэх бөгөөд ингэснээр газар дээрх бүх зүйл амилж, цаашид “аажмаар доош живэхээ” больж, харин эрч хүчтэй уур амьсгал дунд амьдарна. Намайг үүлсийн дунд байхад хүн Миний царай, Миний нүдийг бүдэг бадаг хардаг ба энэ үедээ бага зэрэг айдас мэдэрнэ. Урьд нь тэр Миний тухай түүхэн баримтуудыг домгоос сонссон ба үүний үр дүнд Надад хагас итгэж, хагас эргэлзэж байна. Тэр Миний хаана байгааг, эсвэл Миний царай хэр томыг буюу энэ нь далай шиг өргөн үү, эсвэл ногоон зүлэг шиг хязгааргүй юу гэдгийг мэдэхгүй. Хэн ч эдгээр зүйлийг мэдэхгүй. Хүн Миний царайг өнөөдөр үүлэн дундаас хараад л домогт гардаг Би бол бодит гэдгийг мэдэрнэ, тэгээд Надад арай наашгай хандах ба Миний үйл хэргээс болж л Намайг бахдах нь жаахан ихэснэ. Гэхдээ хүн Намайг мэдэхгүй хэвээр байгаа бөгөөд Миний нэг хэсгийг л үүлэн дундаас хардаг. Дараа нь Би Өөрийн гарыг сунгаж хүнд үзүүлнэ. Хүн гайхширч, гараараа амаа таглан Миний гарт цохиулахаас ихэд айх ба тэгээд бахдалдаа бага зэргийн хүндлэл нэмнэ. Хүн анхааралтай байхгүй л бол Надад цохиулна хэмээн жигтэйхэн айж, Миний хөдөлгөөн бүрийг нүд салгалгүй хардаг—гэхдээ хүн ажигласнаас болж Би хязгаарлагддаггүй, Би гар дахь ажлаа үргэлжлүүлэн хийдэг. Миний хийдэг бүх үйл хэрэг хүнийг Надад илүү таатай ханддаг болгосон ба ингээд яваандаа Надтай харилцах гээд Миний өмнө ирдэг. Би хэн болох нь хүнд бүхэлдээ илчлэгдэх үед хүн Миний царайг харна, түүнээс хойш Би цаашид ахин нуугдахгүй, эсвэл Өөрийгөө хүнээс далдлахгүй. Орчлон ертөнц даяар Би бүх хүнд ил харагдах ба мах цуснаас бүрдсэн хүн бүр Миний үйл хэргийг бүгдийг нь харна. Бүхий л сүнслэг хүмүүс Миний гэрт гарцаагүй амар амгалан орших ба Надтай хамт

гайхалтай ерөөлүүдийг эдлэх нь эргэлзээгүй. Миний анхаардаг бүх хүн гэсгээлтээс гарцаагүй мултрах бөгөөд сүнсний шаналал, бие махбодын зовлонгоос зайлсхийх нь гарцаагүй юм. Би бүх хүнд ил харагдаж, эрх мэдлийг атган ноёрхоно, ингэснээр үхдэлийн үнэр орчлон ертөнцөд тархахаа болино; үүний оронд Миний цэнгэг анхилуун үнэр бүхий л дэлхий даяар тархана, Миний өдөр ойртож байгаа учраас хүмүүс сэрж, газар дээрх бүх зүйл эмх журамдаа орж, газар дэлхийн оршин байх өдрүүд үгүй болж байна, учир нь Би ирчихсэн!

1992 оны 4 дүгээр сарын 6

30-Р БҮЛЭГ

Хүмүүсийн дунд Би нэгэнтээ хүний дуулгаваргүй байдал болон сул талыг нэгтгэн дүгнэсэн бөгөөд тиймээс Би хүний сул талыг ойлгож, түүний дуулгаваргүй байдлыг мэдэж авсан. Хүмүүсийн дунд хүрэлцэн ирэхээсээ өмнө Би хүмүүсийн дундах баяр хөөр, уй гашууг аль эртнээс ойлгодог байсан—үүний улмаас Би хүний чадахгүй зүйлийг хийж, хүний чадахгүй зүйлийг хэлэх чадвартай бөгөөд Би тэдгээрийг маш амархан хийдэг. Энэ нь хүн бид хоёрын хоорондох ялгаа биш гэж үү? Энэ нь тодорхой ялгаа биш гэж үү? Миний ажлыг мах, цусnаас бүрдсэн хүмүүс хийж чадна гэж үү? Би бүтээгдсэн зүйлстэй адил төрлийнх байж болох уу? Хүмүүс Намайг “ижил төстэй зүйл” гэж ангилсан—тэд Намайг мэддэггүй учраас ингэж байгаа биш гэж үү? Хүмүүсийн дунд өндөрт мандахын оронд Би яагаад Өөрийгөө даруу болгох ёстой юм бэ? Яагаад хүн төрөлхтөн Надаас татгалзсаар байдаг вэ, яагаад хүн төрөлхтөн Миний нэрийг тунхаглах чадваргүй байдаг вэ? Миний зүрх сэтгэлд асар их уй гашуу байдаг боловч хүмүүс яаж мэдэх билээ? Тэд яаж харж чадах билээ? Миний санаа зовдог зүйлсийг хэзээ ч өөрсдийн амьдралын хамгийн чухал зүйл гэж үздэггүй байсан болохоор хүмүүс нойрсуулах эм дөнгөж уучхаад байгаа мэт гайхширч, будилж орхижээ; Намайг тэднийг дуудах үед тэд зүүдэлсээр л байсан болохоор хэн ч хэзээ ч Миний үйл хэргийн талаар мэдэж байгаагүй. Өнөөдөр ихэнх хүн бөх нойрссон хэвээр байна. Хаанчлалын сүлд дуу эгшиглэх үед л тэд нойрмог нүдээ нээж, зүрх сэтгэлдээ бага зэргийн уйтгар мэдэрдэг. Миний саваа хүн төрөлхтний дунд буух үед, тэд яг л хувь заяа нь далайн элсний ч үнэ цэнгүй мэт бас л өчүүхэн төдий анхаарал хандуулдаг. Хэдийгээр тэдний ихэнх нь зарим нэг ойлголттой байдаг боловч Миний алхмууд хэр хол ахисныг тэд мэдэхгүй л байгаа—учир нь хүмүүс Миний зүрх сэтгэлийг ойлгох гэж хичээдэггүй, иймээс өөрсдийгөө Сатаны хүлээснээс чөлөөлж хэзээ ч чадаагүй юм. Би бүх зүйлийн дээгүүр хөдөлж, бүх зүйлийн дунд амьдардаг ба үүний зэрэгцээ Би бүх хүний зүрх сэтгэлийн төвд байдаг. Ийм учраас хүмүүс Намайг ер бусын эсвэл ойлгохын аргагүй нэгэн гэж итгээд Намайг өөр гэж хардаг—үр дүнд нь Надад итгэх тэдний

итгэл өдөр ирэх бүр улам хүчтэй болдог. Би нэгэн удаа гуравдагч тэнгэрт хажуулж байгаад орчлон ертөнц дэх бүх хүн болон зүйлийг ажигласан. Намайг унтах үед хүмүүс Миний амралтыг үймүүлэхээс ихэд эмээж чимээгүй болдог. Намайг сэрэх үед тэд нэн даруй хөдөлгөөнд орж, Надад баяр хөөр авчрах ажлыг зориуд хийж байгаа мэт байдаг. Газар дээрх хүмүүсийн Надад хандах хандлага энэ биш гэж үү? Өнөөдрийн хүмүүсийн дундаас хэн нь тэнгэр дэх болон газар дээрх Намайг нэг гэдгийг харсан юм бэ? Тэнгэр дэх Намайг дээдлэн хүндэлдэггүй хэн байна вэ? Мөн газар дээрх Намайг дорд үздэггүй хэн байна вэ? Хүн яагаад Намайг үргэлж тасчин хаядаг юм бэ? Хүн яагаад үргэлж Надад хоёр өөр хандлагаар ханддаг юм бэ? Газар дээрх бие махбодтой болсон Бурхан нь тэнгэрт бүхнийг захирдаг Бурхан биш гэж үү? Тэнгэр дэх Би одоо газар дээр байгаа биш гэж үү? Яагаад хүмүүс Намайг хардаг боловч Намайг мэддэггүй юм бэ? Яагаад тэнгэр газрын хооронд тийм их зай байдаг юм бэ? Эдгээр зүйл хүнээр гүнзгий судлуулах үнэ цэнгүй гэж үү?

Хүмүүсийн үнэрлэх мэдрэхүй нь Минийхээс илүү хурц, тэд хурц амт шимтийг илүүд үздэг аятай, бас Би хүнд юу хэрэгтэйг мэддэггүй болохоор хүнд “төвөг удаж” ажлаа “хамжилцуулах”-гүй л бол болохгүй байдаг юм шиг Намайг ажлаа хийх үед болон айлдвараа өгч байх үеэр хүмүүс үргэлж “хачир” нэмэхийг хүсдэг. Би хүмүүсийн өөдрөг байдлыг санаатайгаар мохоодоггүй боловч Намайг мэдсэний үндсэн дээр өөрсдийгөө цэвэрлэхийг тэднээс хүсдэг. Тэд дэндүү их дутагдалтай учраас Би тэдэнд Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд илүү их хүчин чармайлт гаргаж, түүгээрээ дутагдлуудаа нөхөхийг зөвлөдөг юм. Хүмүүс нэгэн цагт Намайг үзэлдээ мэддэг байсан мөртөө үүнийгээ огт гадарладаггүй байсан, тиймээс тэд элсийг алт мэт үзэж нандигнадаг байв. Намайг тэдэнд сануулахад тэд нэг хэсгээс нь л ангижирсан боловч тэр үгүй болгосон хэсгээ алт, мөнгөн зүйлсээр орлуулахын оронд гартаа үлдсэн хэсгийг л үргэлжлүүлэн эдэлсээр байсан юм—тийм болохоор л тэд Миний өмнө үргэлж даруу агаад тэвчээртэй байдаг; тэд Надтай нийцтэй байх чадваргүй, учир нь тэдэнд хэтэрхий олон үзэл байдаг. Тиймээс хүнд юу байгаа болон тэр юу болох бүхнийг нь Би хурааж аваад, холын холд чулуудахаар шийдсэн, ингэснээр бүгд Надтай хамт амьдарч чадах ба Надаас тусдаа байхаа болих юм. Миний ажлаас болоод хүн Миний хүслийг ойлгодоггүй. Би хоёр дахь удаагаа Өөрийн ажлыг төгсгөж, тэднийг там руу шидэх болно гэж зарим нь итгэдэг. Зарим нь Намайг үг хэлэх шинэ арга барил авч хэрэгжүүлнэ гэж итгэдэг ба тэдний ихэнх нь айн дагждаг: Намайг Өөрийн ажлыг дуусгаад, өөрсдийгөө очих газаргүй болж үлдэнэ гэхээс үлэмж эмээдэг бөгөөд тэднийг Би бас дахин хаяж явах вий гэж үнэхээр айдаг. Миний шинэ ажлыг хэмжихдээ хүмүүс үргэлж хуучин үзлээ ашигладаг. Миний ажилладаг арга барилыг хүмүүс хэзээ ч ухаарч байгаагүй гэж Би хэлсэн—энэ удаа тэд сайн байж чадах болов уу? Хүмүүсийн хуучин үзэл нь Миний ажилд саад болдог зэвсэг биш гэж үү? Намайг хүмүүстэй ярих үед тэд Миний нүд өөр дээр нь тогтох вий гэхээс асар их айж, үргэлж харцнаас минь буруулдаг. Тиймээс тэд Миний үзлэгийг хүлээн зөвшөөрч

буй мэтээр толгойгоо бөхийлгөдөг—энэ нь тэдний үзлээс болсон биш гэж үү? Би Өөрийгөө өнөөдрийг хүртэл даруу болгосоор ирсэн байхад яагаад хэн ч, хэзээ ч анзаараагүй юм бэ? Би хүнд мэхийн ёслох ёстой юу? Би тэнгэрээс газар луу ирсэн, Би өндрөөс нууц газарт буун хүний дунд ирж, Надад байгаа бүхнээ болон Би юу болохоо түүнд илчилсэн. Миний үг чин сэтгэлийн агаад баттай, хүлцэнгүй агаад эелдэг зөөлөн—гэвч Намайг юу болох болон Надад юу байгааг харж байсан хүн хэн байна вэ? Би хүнд нууцлаг хэвээр байгаа юу? Хүнтэй уулзахад Надад яагаад ийм хэцүү байдаг юм бэ? Хүмүүс өөрсдийн ажилд автаад хэтэрхий завгүй байдаг учраас уу? Би Өөрийн үүргийг умартаж, харин хүмүүс бүгд амжилтын хойноос хөөцөлдөх санаатай байдаг учраас уу?

Хүмүүсийн оюун бодолд Бурхан бол Бурхан, Түүнтэй харьцахад амаргүй, харин хүн бол хүн, хүн амархан цадигаа алдаж болохгүй—гэсэн ч хүмүүсийн үйл хэргийг Миний өмнө авчирч болохгүй хэвээр байна. Миний шаардлага хэтэрхий өндөр байна гэж үү? Хүн хэтэрхий сул дорой байна гэж үү? Яагаад хүмүүс Миний шаарддаг стандартыг үргэлж холоос хардаг юм бэ? Тэдгээр нь үнэхээр хүн хүрэхийн аргагүй юм уу? Миний шаардлагууд хүмүүсийн “бие бялдар” дээр үндэслэн тооцоологддог, иймээс хүний биеийн хэмжээнээс хэзээ ч хэтэрч байгаагүй—тэгсэн ч гэсэн хүмүүс Миний шаарддаг хэм хэмжээнд хүрэх чадваргүй хэвээр л байх юм. Тоо томшгүй олон удаа Би хүмүүсийн дунд хаягдсан, Миний бие битүү өргөстэй, тэдний хувьд жигшмээр зүйл аятай хүмүүс Над руу тоо томшгүй олон удаа доогтой харцаар харж байсан, тиймээс хүмүүс Надад зэвүүцэж, хэрэггүй амьтан гэж үздэг. Ийм байдлаар хүмүүс Намайг нааш цааш түлхдэг. Тоо томшгүй олон удаа хүмүүс Намайг бага үнээр гэртээ авчирсан, тоо томшгүй олон удаа тэд Намайг өндөр үнээр худалдсан бөгөөд үүний улмаас Би өнөөдрийн ийм нөхцөл байдалд орчхоод байна. Хүмүүс Надад зориулан арга заль сэдсээр байгаа мэт байдаг; тэдний ихэнх нь Намайг хэдэн зуун сая долларын ашгийн төлөө худалдахыг одоо ч хүсдэг, учир нь хүн хэзээ ч Намайг нандигнан хайрлаж байгаагүй юм. Би хүмүүсийн хоорондын зуучлагч, эсвэл тэдний бие биетэйгээ тэмцэлддэг цөмийн зэвсэг юм уу, эсвэл тэдний хоорондох гарын үсэг зурсан гэрээ болсон мэт байдаг—тийм болохоор Би бол товчхондоо хүний зүрх сэтгэлд огтхон ч үнэ цэнгүй, онцын шаардлагагүй гэр ахуйн бараа юм. Гэсэн ч үүний улмаас Би хүнийг ялладаггүй; Би хүнийг аврахаас өөрийг хийдэггүй бөгөөд хүнд үргэлж энэрэнгүй хандсаар ирсэн билээ.

Хүмүүс Намайг тамтай жич хэлэлцээ хийж байгаа мэт, Намайг хүний наймаагаар дагнасан нэг төрлийн хэлтэс мэт, Намайг хүмүүсийг луйварддаг мэргэжилтэн агаад өөрсдийг нь гартаа оруулмагцаа өндөр үнээр зарчих болохоор хүмүүсийг там руу сэтгэл амар шидчихнэ гэж үздэгг. Хүмүүс аман дээрээ ингэж хэлдэггүй боловч зүрх сэтгэлдээ боддог зүйл нь энэ юм. Хэдийгээр тэд бүгд Намайг хайрладаг боловч үүнийгээ нууцаар хийдэг. Тэдний энэ жаахан хайрын хариуд Би тийм их төлөөс төлж, маш ихийг зарлагадсан гэж үү? Хүмүүс бол хууран мэхлэгчид

бөгөөд Би үргэлж мэхлэгдэгчийн дүрд тоглодог. Би хэтэрхий цайлган юм шиг байдаг: Тэд энэхүү сул талыг хармагцаа Намайг хуурч мэхэлсээр байдаг. Миний амнаас гарсан үг хүмүүсийг үхэлд хүргэж, эсвэл тэдэнд санаан зоргоор шошго наах санаа агуулаагүй—тэдгээр нь хүний бодит байдал юм. Миний зарим үг "хэтэрсэн" байж магадгүй, тийм тохиолдолд Би хүмүүсээс уучлал "гуйж" л чадна; учир нь Би хүний хэлэнд "авьяастай" биш болохоор Миний хэлдэг зүйлийн ихээхэн нь хүмүүсийн шаардлагыг хангах чадваргүй. Миний зарим үг хүмүүсийн зүрх сэтгэлийг нэвт хатгадаг байж магадгүй, иймээс Би тэвчээртэй байхыг л тэднээс "гуйж" чадна; Би хүний амьдралын гүн ухаанд мэргэшээгүй бөгөөд ярих арга барил минь цэгцтэй биш болохоор Миний олон үг хүмүүст ичгэвтэр санагддаг. Миний зарим үг хүмүүсийн өвчин эмгэгийн уг руу нь ярьж, тэдний өвчнийг ил болгодог байж магадгүй, иймээс Миний чамд зориулан бэлтгэсэн эмийг уухыг зөвлөж байна, учир нь Надад чамайг өвтгөх санаа байхгүй бөгөөд энэ эм ямар ч гаж нөлөөгүй. Миний зарим үг "бодитой" сонсогддоггүй байж магадгүй ч Би хүмүүсээс сандарч тэвдэхгүй байхыг "гуйдаг"—Миний гар хөл "хурдан шаламгай" биш, иймээс Миний үг хараахан биелээгүй байгаа. Надад "хүлээцтэй" хандахыг Би хүмүүсээс хүсдэг. Эдгээр үг хүмүүст тустай юу? Хүмүүс эдгээр үгээс ямар нэгэн зүйлийг олж авч чадна гэж, ингэснээр Миний үг үргэлж талаар өнгөрөхгүй гэж Би найдаж байна!

1992 оны 4 дүгээр сарын 9

31-Р БҮЛЭГ

Хүмүүсийн зүрх сэтгэлд Миний орон зай хэзээ ч байгаагүй. Би хүмүүсийг үнэхээр хайх үед тэд нүдээ тас аниад, Миний хийдэг бүхэн тэдний таалалд нийцүүлэх гэсэн оролдлого мэт байдаг, үүний улмаас тэд үргэлж Миний ажил хэрэгт зэвүүцдэг. Надад ямар нэгэн өөрийн ухамсар байхгүй мэт, Би "шулуун шударга, зөв" хүний өмнө үргэлж Өөрийгөө сайрхаж, тэгснээрээ уурыг нь хүргэдэг юм шиг байдаг. Гэвч, тийм тааламжгүй нөхцөл байдлыг ч гэсэн Би тэвчиж, Өөрийн ажлыг үргэлжлүүлдэг. Тиймээс, Би хүний туршлагын чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай амтыг амссан бөгөөд салхиар ирж, бороноор буцдаг гэж Би хэлнэ; Би гэр бүлийн хавчлага, амьдралын эрээн барааныг туулж, бие махбодоос хагацах зовуурийг туулсан гэж Би хэлнэ. Гэвч Намайг газар дээр ирэхэд, өөрсдийнх нь төлөө Миний амссан зовлон бэрхшээлийн улмаас Намайг халуун дотноор угтаж авахын оронд хүмүүс Миний сайн санаанаас "эелдгээр" татгалзсан. Би үүнээс болж шаналахгүй байж яахан чадах билээ? Би гомдохгүй байж яахан чадах юм бэ? Бүхнийг ингэж дуусгах л гэж Би махбод болсон гэж үү? Хүн яагаад Намайг хайрладаггүй юм бэ? Миний хайрыг яагаад хүн үзэн ядалтаар хариулдаг юм бэ? Би ингэж зовох учиртай гэж үү? Газар дээрх зовлон бэрхшээлийг минь хүмүүс

өрөвдөж нулимс унагаж, золгүй явдлын минь шударга бус байдлыг тэд загнасан. Гэвч зүрх сэтгэлийг минь үнэхээр мэдэж байсан хэн байна вэ? Мэдрэмжийг минь ойлгож ухамсарлаж чадах хэн байна вэ? Хүн нэгэн цагт Намайг гэсэн гүн гүнзгий сэтгэлтэй байсан, зүүдэндээ Намайг байнга хүсэн хүлээдэг байсан—гэхдээ газар дээрх хүмүүс тэнгэр дэх Миний хүслийг яахан ойлгож чадах билээ? Хэдийгээр хүмүүс нэгэн цагт Миний уй гашуугийн мэдрэмжийг ойлгож ухамсарласан ч Миний зовлон шаналлыг зовлон нэгтийн хувиар хэн өрөвдөж байсан бэ? Газар дээрх хүмүүсийн мөс чанар, Миний гаслантай зүрх сэтгэлийг хөдөлгөж, өөрчилж чадах болов уу? Газар дээрх хүмүүс зүрх сэтгэл дотроо байгаа үгээр хэлэхийн аргагүй зовлон бэрхшээлийг Надад хэлж чадахгүй байна уу? Сүнс болон сүснүүд бие биеэсээ хамааралтай боловч махан биеийн хил хязгаарын улмаас хүмүүсийн уураг тархи “хяналтаа алдсан.” Би хүмүүст Өөрийнхөө өмнө ирэхийг нэгэнтээ сануулсан боловч, Миний дуудлага хүмүүсийг гуйсан зүйлийг минь биелүүлэхэд хүргээгүй; тэд үгээр хэлэхийн аргагүй зовлон бэрхшээл тээж байгаа мэт, тэдний замд ямар нэгэн зүйл хөндөлсөж буй мэт тэд ердөө л тэнгэр лүү нулимс дүүрэн нүдээр ширтэж байсан. Тиймээс, тэд Надаас гуйн тэнгэрийн дор алгаа хавсран, мэхийн ёсолсон. Өршөөнгүй учраас Би хүмүүсийн дунд ерөөлөө хайрлаж, өөрийн биеэр Би хүмүүсийн дунд ирэх цаг мөч нүд ирмэхийн зуурт ирнэ—гэсэн ч хүн Тэнгэрт өгсөн тангаргаа аль хэдийн мартчихсан байсан. Энэ нь хүний өнөө дуулгаваргүй байдал бус уу? Хүн яагаад үргэлж “мартаж санах өвчтэй” байдаг юм бэ? Би түүнийг хутгалсан уу? Би түүний биеийг цохин унагасан уу? Би Өөрийн зүрх сэтгэлдээ байгаа мэдрэмжүүдийг хүнд хэлдэг; тэр яагаад үргэлж Надаас зайлсхийдэг юм бэ? Хүмүүсийн ой санамж нь ямар нэгэн зүйлээ алдаад хаанаас ч олохгүй байгаа мэт байдаг боловч, бас ой санамж нь үнэн зөв биш мэт байдаг. Тиймээс хүмүүс амьдралдаа үргэлж мартамхай, бүх хүн төрөлхтний амьдралын өдрүүд нь эмх замбараагүй байдаг. Гэсэн ч, хэн ч үүнийг шийдвэрлэх зүйл хийдэггүй; хүмүүс бие биеэ дэвсэлж, хөнөөхөөс өөр зүйл хийдэггүй нь өнөөдрийн гамшигт ялагдлын байдалд хүргэж, орчлон ертөнц дэх бүхнийг аврагдах ямар ч боломжгүйгээр бохир заваан ус, шавар шавхай руу нуран унахад хүргэсэн.

Би бүх хүний дунд ирсэн үе нь хүмүүс Надад үнэнч болсон яг тэр цаг үе байсан. Энэ үед агуу улаан луу бас хөнөөлт гараараа хүмүүсийг барьж авч эхэлсэн. Би “урилгыг” хүлээн авч, хүмүүсийн дунд “найрын ширээнд суухаар”, хүн төрөлхтнөөс Надад өгсөн “урьсан захиаг” барин ирсэн. Намайг хараад хүмүүс Надад анхаарал хандуулаагүй, учир нь Би Өөрийгөө тансаг хувцсаар гоёогүй бөгөөд хүнтэй хамт ширээнд суухын тулд зөвхөн Өөрийн “биеийн байцаалтыг” л авчирсан билээ. Нүүрэн дээр минь үнэтэй цайтай энгэсэг, тэргүүн дээр минь титэм байгаагүй, Би хөлдөө ердөө л энгийн гар хийцийн гутал өмссөн байсан. Хүмүүсийн урмыг хамгийн их хугалсан зүйл нь Миний уруул дээр уруулын будаг байгаагүй явдал юм. Түүнээс гадна, Би ёсорхуу үг хэлээгүй, хэл минь зохиолчийн үзэг мэт бэлэн зэлэн байгаагүй; харин ч Миний үг нэг бүр, хүний зүрх сэтгэлийн гүнийг нэвт хатгасан нь Миний амны

талаарх хүмүүсийн “эерэг” сэтгэгдэлд зарим талаар нэмэрлэсэн. Хүмүүс Надад “тусгай үйлчилгээ” үзүүлэхэд дээр дурдсан харагдах байдал хангалттай байсан учраас тэд Надтай, хорвоогийн талаар мэдлэггүй, мэргэн ухаангүй хөдөөний тэнэг амьтан шиг харьцсан. Хүн болгон “бэлгийн мөнгө” гардуулах үед ч гэсэн хүмүүс Намайг хүндтэй хүн гэж үзэхгүй хэвээр, Миний өмнө ямар ч хүндлэлгүйгээр, хөлөө чирэн цухалдан ирсэн. Намайг гараа сунгахад тэд тэр дороо мэл гайхаж, өвдөг сөгдөн, асар ихээр уулга алдсан. Тэд Миний бүх “бэлгийн мөнгийг” хураан авсан. Мөнгөний хэмжээ нь асар их байсан учраас тэд, тэр даруй Намайг саятан хэмээн бодож, Миний зөвшөөрөлгүйгээр ноорхой хувцсыг биеэс минь урж тастан салгаж, шинэ хувцаар сольсон—гэсэн ч энэ нь Намайг баярлуулаагүй. Би ийм амар хялбар амьдралд дасаагүй, ийм “дээд зэрэглэлийн” үйлчилгээг жигшдэг, Би ариун гэрээс төрсөн учраас, Би “ядуу тарчиг” байдалд төрсөн болохоор хүмүүсийг гар хөлийнхөө үзүүрт зарсан тансаг амьдралд дасаагүй гэж хэлж болно. Хүмүүс Миний зүрх сэтгэл дэх мэдрэмжийг ойлгож, Миний амнаас гарах тааламжгүй үнэнийг хүлээн зөвшөөрөхийн тулд бага зэргийн зовлон бэрхшээлийг туулаасай гэж л Би хүсдэг. Би хэзээ ч онол ярьж чадахгүй, бас хүмүүстэй харилцахын тулд нийгэмд биеэ авч явах нууц аргыг нь ашиглах чадваргүй, мөн үгээ хүмүүсийн төрх байдал, сэтгэлзүйд нь тааруулах чадваргүй учраас хүмүүс үргэлж Намайг жигшиж, өөрсөдтэй нь харилцах гавьяа Надад байхгүй гэж итгэж, Миний үг хэл хурц агаад хүмүүсийг үргэлж шархлуулдаг гэж хэлсэн юм. Гэвч Надад ямар ч сонголт байхгүй: Би хүмүүсийн ярьдаг арга барилыг эзэмшиж, төрх байдалд нь тааруулан ярьж магадгүй гэсэндээ нэгэн цагт хүний сэтгэлзүйг “судалж”, хүний амьдралын гүн ухааныг “дуурайж”, хүний хэлийг сурахын тулд нэгэн цагт “хэлний коллежид” сурсан—гэвч хэдий Би маш их хичээл чармайлт гаргаж, олон “мэргэжилтнүүд” дээр очсон боловч бүгд талаар болсон. Надад хүн чанарын юу ч, хэзээ ч байгаагүй. Энэ олон жилийн турш Миний хичээл зүтгэлээс хэзээ ч, өчүүхэн төдий ч үр дүн гараагүй, Надад хүний хэлний өчүүхэн ч авьяас хэзээ ч байгаагүй. Тиймээс “ажил хийвэл ам тостоно” хэмээх хүний үг Надаас “ойн” одсон бөгөөд үүний үр дүнд эдгээр үг газар дээр төгссөн. Хүмүүсийг ухаараагүй байхад энэхүү онч мэргэн үгийг тэнгэрээс ирсэн Бурхан няцааж, тиймэрхүү үг байж болшгүй гэдгийг хангалттай баталсан. Тиймээс Би хүнээс уучлал гуйдаг боловч үүнийг яах ч аргагүй—тийм “тэнэг” байсныхаа төлөө Би үүнийг хүртсэн. Би хүний хэлийг сурч, амьдралын гүн ухаанд дадамгай болж, хүмүүстэй нийгэмших чадваргүй. Би хүмүүст тэсвэр хатуужилтай байж, зүрх сэтгэлийнхээ дотор байгаа уураа дарж, Надаас болж өөрсдийгөө шархлуулахгүй байхыг л зөвлөж чадна. Хэн биднийг нэг нэгэнтэйгээ харьцахад хүргэсэн бэ? Хэн биднийг энэ мөчид уулзуулсан бэ? Хэн биднийг ижил үзэл санаатай болгосон бэ?

Миний зан чанар, Миний бүх үгэнд нэвт шингэсэн байдаг ч, хүмүүс Миний үгээс үүнийг ухаарч чаддаггүй. Тэд ердөө л Миний хэлсэн зүйлийн талаар шал дэмий зүйл ярьдаг—тэгээд ямар хэрэг байна? Миний тухай үзэл нь тэднийг төгс болгож

чадах уу? Газар дээрх зүйлс Миний хүслийг гүйцэлдүүлж чадах уу? Миний үгийг хэрхэн ярихыг Би хүмүүст заахаар оролдсоор байсан ч хүн амаа үдүүлсэн мэт байж, Миний хүссэнээр Миний үгийг хэрхэн ярихыг хэзээ ч сурч чадаагүй. Би түүнд үг бүрчлэн заасан ч, тэр хэзээ ч сурч чадаагүй юм. Үүний дараагаар л Би шинэ зүйл олж мэдсэн: Газар дээрх хүмүүс тэнгэрийн үгийг ярьж яахан чадах билээ? Энэ нь байгалийн хуулийг зөрчих бус уу? Гэхдээ хүмүүсийн урам зориг, Надад хандах сониуч зангийн улмаас Би хүн дээр хийх ажлын өөр нэг хэсгийг эхлүүлсэн. Би хүнийг дутагдлаас нь болж хэзээ ч ичээж байгаагүй, харин ч дутагдаж байгаа зүйлд нь нийцүүлэн хүнийг хангадаг. Зөвхөн үүний улмаас л хүмүүс Миний талаар бага зэргийн эерэг сэтгэгдэлтэй байдаг бөгөөд Миний баялгийн өөр нэг хэсгийг эдлээсэй гэсэндээ Би энэ боломжийг ашиглаж, хүмүүсийг дахин нэг удаа цуглуулдаг. Энэ мөчид хүмүүс, дахин нэгэнтээ тэнгэр дэх олон өнгөт үүлэн дундуур хөвөх аз жаргал, баяр хөөр, инээд наргианд автдаг. Би хүний зүрх сэтгэлийг нээж, хүн нэн даруй шинэ эрч хүчтэй болж, Надаас цаашид нуугдахыг хүсдэггүй, учир нь тэр зөгийн балын чихэрлэг амтыг амсаж үзсэн болохоор Би хог цуглуулах цэг, эсвэл хог хаягдлын менежментийн цэг болсон мэт бүх хогоо солихоор гаргаж ирдэг. Тиймээс гаргаж тавьсан “зарыг” харсныхаа дараа хүмүүс, Миний өмнө ирж, идэвхтэйгээр оролцдог, учир нь тэд, хэдэн “бэлэг дурсгал” олж авч чадна гэж боддог юм шиг харагддаг, иймээс тэд бүгд Миний зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож магадгүй гэж Надад “захиа” илгээдэг. Эдгээр үйл ажиллагааны “хөрөнгө мөнгө” тийм ч их биш учраас энэ мөчид тэд алдагдлаас айдаггүй, иймээс тэд оролцох эрсдэлийг үүрч зүрхэлдэг. Хэрвээ оролцсоноор олж авч болох бэлэг дурсгал байгаагүй бол хүмүүс үйл ажиллагааны талбарыг орхин явж, мөнгөө буцаан авахаар шаардаж, мөн Миний тэдэнд төлөх ёстой “хүүг” тооцоолох байсан. Өнөөгийн амьдралын стандарт өсөж, “хөгжил цэцэглэлтийн даруухан түвшинд” хүрч, “дээд албан тушаалтнууд” ажил зохицуулахын тулд биечлэн “хөдөө явснаар” “шинэчлэлтэд” хүрсэн учраас хүмүүсийн итгэл нэн даруй олон дахин өссөн—мөн тэдний “бие хаа” улам илүү сайн болсон учраас тэд Над руу бахдалтайгаар харж, Миний итгэлийг олж авахын тулд Надтай харилцахыг хүсэж байгаа.

1992 оны 4 дүгээр сарын 11

32-Р БҮЛЭГ

Хүмүүс Миний дэргэд цугларахад зүрх сэтгэл минь баяр хөөрөөр дүүрдэг. Тэр даруй Би гартаа байгаа ерөөлийг хүмүүсийн дунд хайрлаж, тэгснээр хүмүүс Надтай хамт чуулж, Надад тэрсэлдэг дайснууд биш, харин Надтай эвтэй байдаг найзууд болдог. Тиймээс Би бас хүнд үнэн сэтгэлээсээ ханддаг. Өөрийн ажилд Би хүнийг өндөр түвшний байгууллагын гишүүн гэж хардаг учраас түүнд илүү их анхаарал

хандуулдаг, учир нь тэр үргэлж Миний ажлын бай байсаар ирсэн билээ. Би хүмүүсийн зүрх сэтгэлд Өөрийн орон зайг бий болгосон болохоор зүрх сэтгэл нь Намайг биширдэг хэдий ч Намайг яагаад үүнийг хийдэг талаар тэд огт мэдэхгүй хэвээр үлдэж, хүлээхээс өөрийг хийдэггүй. Хэдийгээр хүмүүсийн зүрх сэтгэлд Миний бий болгосон орон зай байдаг ч тэндээ амьдрахыг тэд Надаас шаарддаггүй. Харин ч тэд өөрсдийн зүрх сэтгэл дэх “Ариун Нэгнийг” гэнэт хүрэлцэн ирэхийг хүлээдэг. Миний ялгамж чанар хэтэрхий “дорд” учраас хүмүүсийн шаардлагад Би нийцдэггүй, тиймээс тэд Намайг таягдан хаясан. Тэдний хүсдэг зүйл нь өндөр дээд, төгс хүчит “Би” боловч ирэх үедээ Би хүнд ингэж харагдаагүй болохоор тэд алсыг харуулдан, өөрсдийн зүрх сэтгэл дэх нэгнийг хүлээсээр байдаг. Хүмүүсийн өмнө ирэх үед тэд Намайг олон түмний өмнө голсон. Хүний “харьцахыг” хүлээн, хүмүүс Намайг буюу энэ дутуу дулимаг “бүтээлийг” эцэст нь яахыг хөндлөнгөөс харж зогсохоос өөр арга Надад байгаагүй. Би хүмүүсийн шархыг биш, харин шархлаагүй хэсгийг нь харж, үүнээс Би баяр хөөрийг олж авдаг. Хүмүүсийн нүдэнд Би ердөө л тэнгэрээс бууж ирсэн “бяцхан од”, Би зүгээр нэг тэнгэр дэх хамгийн өчүүхэн зүйл, Намайг өнөөдөр газар дээр ирэхийг Бурхан даалгасан. Ийм учраас хүмүүс “Би” болон “Бурхан” хэмээх үгсийн талаар илүү олон тайлбарыг бодож олсны дээр Намайг Бурхан гэж үзэхээс гүнээ эмээдэг. Миний дүр төрхөд Бурханы зүс царайн юу ч байдаггүй учраас Намайг Бурханы гэр бүлээс гаралтай биш, зарц нь гэдэгт хүмүүс бүгд итгэж, Бурханы дүр төрх ийм биш гэж тэд хэлдэг. Бурханыг харсан хүмүүс магадгүй байж болох ч газар дээрх мэдлэг ухаан минь дутмагийн улмаас Бурхан Надад хэзээ ч “илрэн харагдаагүй”. Магадгүй Би хэтэрхий бага “итгэлтэй” учраас хүмүүс Намайг дорд үздэг. Бурхан бол Бүтээгч учраас хэрвээ хэн нэгэн үнэхээр Бурхан мөн бол тэрээр хүний хэлийг сайн мэддэг байх нь гарцаагүй гэж хүмүүс төсөөлдөг. Гэхдээ бодит байдал бол яг эсрэгээрээ: Би хүний хэлийг сайн мэдэхгүйгээр үл барам түүний “дутуу хөтүүг” “хангаж” чадахгүй үе ч Надад байдаг. Ийм учраас бага зэрэг “буруутай” мэдрэмж Надад төрдөг, учир нь Би хүмүүсийн “шаардсанаар” үйлддэггүй, харин ердөө л “дутагдаж” байгаа зүйлийнх нь дагуу эд материал болон ажлыг нь бэлддэг. Би хүнээс тийм ихийг шаарддаггүй ч хүмүүс ингэж боддоггүй. Тиймээс хөдөлгөөн болгонд нь “даруу төлөв зан” нь илэрдэг. Тэд үргэлж Миний урд Намайг хөтлөн явах үүрэгтэй, Намайг төөрөхөөс ихэд эмээж Намайг уулын гүн дэх аглаг ой руу тэнүүчлэн явахаас ухаангүй айдаг. Ийм учраас хүмүүс Намайг үргэлж урагш хөтөлж, Намайг гяндан руу орох вий гэхээс ихэд айдаг. Хүмүүсийн итгэлийн талаар Би бага зэрэг “таатай сэтгэгдэлтэй” байдаг, учир нь хүмүүс Миний төлөө нойр хоолоо умартан, бүр үсээ бууралттал нойргүй өдөр шөнөгүй “хөдөлмөрлөсөн”—тэдний итгэл орчлон ертөнцийг “даван гарч”, эрин үеүдийн туршид байсан элч нар болон эш үзүүлэгчдээс “илүү гарсан” гэдгийг харуулахад энэ нь хангалттай юм.

Би хүмүүсийн агуу ур чадвараас нь болж хөөрөн алга ташдаггүй, бас дутагдлаас нь болж тэдэнд хөндий хүйтэн ханддаггүй. Би ердөө л Өөрийн гарт байгаа зүйлийг

хийдэг. Би хэнд ч онцгойлон ханддаггүй харин Өөрийн төлөвлөгөөний дагуу л ажилладаг. Гэсэн ч хүмүүс Миний хүслийг мэддэггүй, Миний тэдэнд хайрласан эд баялаг шаардлагад нь нийцэж чадахгүй байгаа мэт, эрэлт нь нийлүүлэлтээсээ давсан мэт Надаас юм гуйн залбирсаар байдаг. Гэхдээ өнөөдрийн эрин үед “ханш уналт” болж байгааг хүмүүс бүгд ойлгодог—ийм учраас тэднийг эдэл гэж Миний өгсөн зүйлс гарт нь дүүрэн байдаг. Үүний улмаас л тэд Надаас залхаж эхэлсэн болохоор тэдний амьдрал эмх замбараагүй байдлаар дүүрэн, юу идэх ёстой, юу идэх ёсгүйгээ тэд мэддэггүй. Зарим нь бүр Миний тэдэнд эдэл гэж өгсөн зүйлсийг гартаа атгачхаад сайтар ажигладаг. Хүмүүс өлсгөлөнгөөс болж зовдог байсан, тэдний хувьд өнөөдөр ийнхүү жаргал цэнгэлд хүрэх нь амаргүй зүйл байсан учраас тэд бүгд “эцэс төгсгөлгүй талархдаг” бөгөөд Надад хандах тэдний хандлагад бага зэргийн өөрчлөлт гарсан. Тэд Миний өмнө уйлсаар байдаг; Би тэдэнд маш ихийг өгсөн учраас тэд Миний гараас барьж, “талархлын дуу” гаргасаар байдаг. Би орчлон ертөнц дээгүүр алхаж явахдаа бүхий л орчлон ертөнцийн хүмүүсийг ажигладаг. Газар дээрх бөөн хүн дундаас Миний ажилд тохиромжтой, Намайг үнэхээр хайрладаг хүн хэзээ ч байгаагүй. Тиймээс энэ мөчид Намайг сэтгэл хямран санаа алдахад хүмүүс нэн даруй дахин цугларахгүйгээр таран одож, тэднийг “бүгдийг нь нэг тороор барих” вий гэхээс ихэд эмээдэг. Би энэ боломжийг ашиглан энэ тарж бутарсан хүмүүсийн дунд хийхэд тохиромжтой ажлаа гүйцэтгэхээр хүмүүсийн дунд ирж, дээр нь ажиллахад тохиромжтой хүмүүсийг сонгодог. Би хүмүүсийг Өөрийн гэсгээлт дунд хэзээ ч зугтаалгахгүйгээр “хорихыг” хүсдэггүй. Би хийх ёстой ажлаа л хийдэг. Би хүний “тусламжийг” хүсэхээр ирсэн; Миний удирдлагад хүний үйл хэрэг дутагддаг учраас Өөрийн ажлыг амжилттай дуусгах боломжгүй байна, Миний ажил үр ашигтайгаар урагшлахад энэ нь саад болдог. Хүмүүс Надтай хамтран ажиллахаар шийдсэн байгаасай л гэж Би найддаг. Надад сайхан хоол хийж өгч, Надад толгой хоргодоход тохирох газрыг зохицуулж өгч, Надад сайхан хувцас хийж өгөхийг Би тэднээс гуйхгүй—Би эдгээр зүйлийг өчүүхэн төдий ч тоодоггүй. Хүмүүс Миний хүслийг ойлгож, Надтай хамт мөр зэрэгцэн урагшилж чаддаг болсон үед Миний зүрх сэтгэл хангалуун болох болно.

Газар дээр хэн Намайг зүрх сэтгэлээсээ хүлээж авсан бэ? Хэн Намайг зүрх сэтгэлээсээ хайрласан бэ? Хүмүүсийн хайр үргэлж шингэлсэн байдаг, тэдний хайрыг яагаад хатааж, шингэлээгүй болгож болдоггүйг Би хүртэл “мэдэхгүй.” Тиймээс хүний дотор маш олон “нууцууд” бас агуулагдаж байдаг. Бүтээгдсэн зүйлсийн дундаас хүнийг “гайхалтай” агаад “ойлгошгүй” нэгэн гэж үздэг учраас Миний өмнө тэр “эрдэм чадалтай”, Надтай адил байр суурьтай мэт байдаг—гэхдээ өөрийнх нь энэ “байр суурь” түүнд ердөө ч хачин санагддаггүй. Би хүмүүсийг энэ байр сууринд зогсож, үүнийг эдлэхийг нь зөвшөөрдөггүйдээ биш харин тэднийг зүй ёсны мэдрэмжтэй байж, өөрсдийгөө хэтэрхий өндрөөр бүү үнэлээсэй л гэж Би хүсдэг; тэнгэр газрын хооронд зай байдаг, Бурхан хүний хоёрын хоорондох зайг ярихын ч хэрэггүй. Бурхан хүн хоёрын хоорондох зай бүр ч илүү их бус уу? Газар

дээр хүн бид хоёр “нэг завин дээр байгаа”, бид “бэрхшээлийг хамтдаа даван туулдаг.” Ялгамж чанар минь Намайг хүний ертөнцийн бэрхшээл зовлонг туулахаас чөлөөлдөггүй, үүний улмаас өнөөдөр Би ийм нөхцөл байдалд орсон. Газар дээр амар тайван амьдрах газар Надад хэзээ ч байгаагүй, ийм учраас хүмүүс “хүний Хүүд толгой хоргодох газар хэзээ ч байгаагүй” гэж хэлдэг. Ийм учраас хүмүүс мөн Намайг өрөвдөн хайрлаж нулимс урсган, Надад зориулан “тусламжийн санд” хэд арван юань хадгалсан. Зөвхөн үүний улмаас Би амрах газартай болсон; хэрвээ хүмүүсийн “тусламж” байгаагүй бол Би хаана балрах байсныг хэн мэдэх билээ!

Миний ажил дуусах үед Би энэхүү “санхүүгийн тусламжийг” хүнээс хүсэхээ болино; харин Би Өөрийн төрөлх чиг үүргээ биелүүлж, “Өөрийн гэрийн бүх зүйлийг” хүмүүст эдлүүлэхээр доош нь буулгах болно. Өнөөдөр Миний шалгалтуудын дунд хүн бүхэн туршигддаг. Би албан ёсоор гараа хүн дээр тавихад хүмүүс Намайг биширсэн нүдээр харахаа больж, харин Намайг үзэн ядах тэр мөчид Би тэдний зүрх сэтгэлийг жишээ болгон нэн даруй гаргаж тавих болно. Хүний зүрх сэтгэлийг Би “микроскопоор” шинжиж харахад Намайг гэсэн жинхэнэ хайр тэдэнд байдаггүй. Олон жилийн турш хүмүүс Намайг мэхэлж, Намайг хуурсаар ирсэн—тэдний зүрхний зүүн тосгуур, баруун ховдол хоёулаа Надад чиглэсэн үзэн ядалтын хорыг агуулдаг болж таарсан. Тэгэхээр Би тэдэнд тэгж ханддагт гайхах зүйлгүй. Гэсэн ч тэд үүнийг огт мэдэхгүй хэвээр үлдсэн агаад үүнийгээ хүлээн зөвшөөрдөг ч үгүй. Би Өөрийн судалгааны үр дүнг тэдэнд харуулахад ч гэсэн тэд мөн л сэрдэггүй; тэдний оюун санаанд эдгээр нь бүгд өнгөрсөн үеийн хэрэг явдлууд, өнөөдөр дахин сөхөх учиргүй мэт байдаг. Тиймээс хүмүүс “лабораторийн хариуг” зүгээр л хайхрамжгүй харчхаад хүснэгтийг буцааж өгөөд алхан оддог. Цаашлаад тэд “Эдгээр нь чухал биш, миний эрүүл мэндэд ямар ч нөлөө үзүүлэхгүй” гэх мэт зүйлийг хэлдэг. Тэд басамжилсан инээмсэглэл бага зэрэг тодруулахын зэрэгцээ нүд нь үл ялиг заналхийлсэн харцтай байгаа нь Намайг ийм илэн далангүй байх хэрэггүй, хааш яаш байх ёстойг битүүхэн сануулж буй мэт байдаг. Би тэдний дотоод нууцыг илчилсэн нь хүний “хуулийг” зөрчсөн учраас Намайг тэд улам илүү үзэн яддаг болсон мэт байдаг. Тэр үед л Би хүмүүсийн үзэн ядалтын эх үүсвэрийг хардаг. Учир нь Намайг харж байхад тэдний цус урсаж бие дэх артерийн судсаар нь явсаар зүрхэнд орох энэ үед л Би шинэ “нээлт” хийдэг. Гэсэн ч хүмүүс энэ талаар юу ч боддоггүй. Тэд огт хайхрахгүй, юу олж авч эсвэл алдаж байгаагаа боддоггүй нь “амь биеэ хайрлалгүй” зориулдаг сэтгэлийг нь харуулахад хангалттай юм. Тэд эрүүл мэндийн байдлаа огт анхаардаггүй, Миний төлөө “яаран эргэлддэг.” Энэ нь мөн тэдний “итгэл үнэмшил”, тэдний талаарх “магтууштай” зүйл, иймээс Би дахин нэгэнтээ тэдэнд “магтаалын” захиа илгээж тэднийг баярлуулж магад юм. Гэхдээ тэдний хийдэг бүхнийг Миний чимээгүй захиа голсон учраас энэ “захиаг” уншихдаа тэд тэр дороо бага зэрэг залхдаг. Би хүмүүсийн үйлдлийг үргэлж залж чиглүүлсэн боловч тэд Миний үгэнд зэвүүцдэг мэт санагддаг; тиймээс Намайг ам ангаймагц

тэд нүдээ чанга аньж, чихээ гараараа тагладаг. Миний хайрын улмаас тэд Намайг хүндэтгэж хардаггүй атлаа Намайг алдаа дутагдлыг нь хэлж өгч, эзэмшил дэх бүх барааг нь ил болгосны төлөө тэд үргэлж Намайг үзэн ядсан, тиймээс бизнес нь алдагдал хүлээж, амин зуулгагүй болсон. Ингээд Намайг үзэн ядах сэтгэл нь нэмэгдэнэ.

1992 оны 4 дүгээр сарын 14

33-Р БҮЛЭГ

Миний ариун нэрийг шагшин магтаж, газар дээрх Миний алдрыг огторгуйд түгээхийн тулд эцэж цуцалгүй ажилладаг хүмүүс урьд Миний гэрт байлаа. Ийм учраас Би баярлан хөөрч, Миний зүрх сэтгэл бахдалаар дүүрсэн—гэвч хэн Миний оронд өдөр шөнөгүй нойроо тэвчин ажиллаж чадах юм бэ? Миний өмнө хүний шийдэмгий байх нь Надад таашаал өгдөг боловч түүний тэрслүү байдал Миний уурыг хүргэдэг, тиймээс хүн үүргээ хэзээ ч сахьж чаддаггүй учраас түүний төлөө Миний уй гашуу улам ихэсдэг. Надад өөрсдийгөө зориулах чадвар хүмүүст яагаад дандаа байдаггүй юм бэ? Яагаад тэд Надтай наймаацах гэж үргэлж оролддог юм бэ? Би худалдааны төвийн ерөнхий менежер үү? Хүмүүсийн Надаас шаардсан зүйлийг Би үнэн сэтгэлээсээ биелүүлдэг, гэтэл хүнээс Миний хүссэн зүйл яагаад талаар өнгөрдөг юм бэ? Би бизнесийн арга замд мэргэшээгүй харин хүн мэргэшсэн байж болох уу? Хүмүүс яагаад Намайг үргэлж зөөлөн яриа, бялдуучлалаар мэхэлдэг юм бэ? Хүмүүс Яагаад арын хаалга асуун үргэлж “бэлэг” барин ирдэг юм бэ? Ингэж бай гэж Би хүнд заасан уу? Хүмүүс яагаад тийм зүйлсийг хурдан, цэвэрхэн хийдэг юм бэ? Яагаад хүмүүс үргэлж Намайг мэхлэх сэдэл гаргадаг юм бэ? Намайг хүн төрөлхтний дунд байхад хүмүүс Намайг бүтээгдсэн зүйл гэж хардаг; Намайг гуравдагч тэнгэрт байхад тэд Намайг бүх зүйлийг ноёрхдог Төгс Хүчит гэж тооцдог; Намайг огторгуйд байхад тэд Намайг бүх зүйлийг дүүргэдэг Сүнс гэж үздэг. Товчхон хэлбэл, хүмүүсийн зүрх сэтгэлд Надад тохирох зай байхгүй. Би урилгагүй зочин юм шиг байж, хүмүүс Намайг жигшдэг, тиймээс Намайг тасалбар аваад суудалдаа суухад тэд Намайг хөөн гаргаж, Надад суух газар энд хаана ч байхгүй, буруу газар ирчихжээ гэдэг болохоор уурлаж хилэгнэсэн Би явахаас өөр аргагүй болдог. Би хүнтэй дахиж харилцахгүй байхаар шийдсэн, учир нь хүмүүс хэтэрхий явцуу бодолтой бөгөөд тэдний уужим сэтгэл хэтэрхий хомс билээ. Би цаашид тэдэнтэй хамт нэг ширээнд хооллохгүй, Би цаашид газар дээр тэдэнтэй хамт цаг өнгөрүүлэхгүй. Гэхдээ Намайг ярихад хүмүүс гайхширдаг; Намайг явна гэхээс айдаг бөгөөд иймээс Намайг хорьсоор байдаг. Тэдний хуурамч занг хараад Миний зүрх сэтгэлд шууд нэг л баргар, золгүй санагддаг. Би тэднийг орхиж явна гэхээс хүмүүс айдаг бөгөөд тиймээс Намайг тэднээс хагацах үед уйлах дуу тэр

даруй газар нутгаар түгэж, хүмүүсийн нүүр царай нулимсаар бүрхэгддэг. Би тэдний нулимсыг арчиж, тэднийг дахин нэгэнтээ өргөж, тэд Намайг ширтэн, гуйж гувшсан нүд нь Надаас явахгүй байхыг гуйж байх шиг, мөн тэдний “чин сэтгэлийн” улмаас Би тэдэнтэй хамт байна. Гэсэн ч Миний зүрх сэтгэлийн зовуурийг хэн ойлгож чадах билээ? Миний үгээр илэрхийлэхийн аргагүй зүйлсийг хэн хайхардаг вэ? Хүмүүсийн нүдэнд Би сэтгэл хөдлөлгүй мэт байдаг, иймээс бид үргэлж хоёр өөр гэр бүлээс гаралтай байсан юм. Миний зүрх сэтгэл доторх уй гашуугийн мэдрэмжийг тэд хэрхэн харж чадах юм бэ? Хүмүүс зөвхөн өөрсдийн хувийн зугаа цэнгэлд шунадаг бөгөөд Миний хүслийн талаар хайхрамжгүй байдаг, учир нь өнөөг хүртэл хүмүүс Миний удирдлагын төлөвлөгөөний зорилгын талаар мэдэхгүй хэвээр үлдсэн, иймээс өнөөдөр тэд чимээгүй хүсэлт тавьсаар байгаа—энэ нь ямар ач тустай юм бэ?

Хүмүүсийн дунд амьдрах үедээ Би хүмүүсийн зүрх сэтгэлд тодорхой байр эзэлдэг; Би бие махбодтойгоор илрэн гарч ирсэн ба хүмүүс “хуучин” бие махбодод амьдардаг учраас тэд үргэлж Надад махан биеэр ханддаг. Хүмүүс зөвхөн махан бие эзэмшдэг агаад өөр дайвар байхгүй учраас “өөрт байгаа бүхнээ” Надад өгсөн юм. Гэсэн ч тэд юу ч мэддэггүй; тэд зүгээр л Миний өмнө “өөрсдийн сүсэг бишрэлийг өргөл болгодог”. Миний хүртдэг зүйл бол ямар ч үнэ цэнэгүй хог—гэсэн ч хүмүүс тэгж боддоггүй. Би тэдний өгсөн “бэлгүүдийг” Өөрийн зүйлстэй харьцуулах үед хүмүүс Миний эрхэм нандин байдлыг хоромхон зуур танин мэддэг ба зөвхөн тэр үед л Миний хэмжээлшгүй байдлыг хардаг. Тэдний магтаалаас болж Би бахаддаггүй, гэвч хүнд харагддаг хэвээр болохоор хүмүүс бүгд Намайг бүрэн дүүрэн мэдэж болох юм. Би тэдэнд Өөрийгөө бүхэлд нь харуулахад Намайг нүдээ бүлтийлгэн ширтэж, Миний өмнө давсан багана мэт хөдөлгөөнгүй зогсдог. Тэдний хачин байдлыг хараад Би инээдээ арай ядан барьдаг. Тэд Надаас юм авахаар гараа сарвайж байгаа учраас Би Өөрийн гарт буй зүйлсийг тэдэнд өгдөг бөгөөд тэд тэдгээрийг дөнгөж төрсөн нярай мэт нандигнан цээжиндээ тэвэрдэг, тэдний хийдэг хөдөлгөөн нь агшин зуурынх л байдаг. Би оршин суудаг орчныг нь өөрчлөхөд нөгөө “нярай хүүхдээ” даруй нэг тийш хаяад толгойгоо барин зугтаадаг. Хүмүүсийн нүдэнд Би бол цаг хугацаа, орон зайнаас үл хамааран байж байдаг туслагч; Би түүнийг дуудангуут очдог үйлчлэгч юм шиг байдаг. Тиймээс хүмүүс Намайг гай гамшигтай тэмцэх хязгааргүй хүч чадлыг эзэмшдэг мэтээр үргэлж “биширч” ирсэн тул тэдэнд Захирагч байдаг гэдгийг бүх зүйл харж болно, тэгэхээр хэн ч өөрсдийг нь хуурч зүрхлэхгүй гээд Намайг дагуулж газар нутгаар аялахдаа үргэлж Миний гараас барьдаг байв. Би хүмүүсийн “барын сүр хүчийг олж авсан үнэгний” заль мэхийг аль эртнээс андахгүй болсон, учир нь тэд бүгд “өөрсдийн бизнесээ эхлүүлж”, ов залиар ашиг олохыг хүсдэг. Би тэдний муу санаатай, хорлонтой арга ухааныг эртнээс андахгүй болсон бөгөөд Би зүгээр л өөрсдийн харилцаагаа сүйтгэхийг хүсдэггүй. Би оргүй хоосноос асуудал үүсгэдэггүй—тэгэх нь ямар ч үнэ цэнэ, ач холбогдолгүй. Би зүгээр л хүмүүсийн сул талуудыг харгалзан үзэж хийх

ёстой ажлаа хийдэг; эс бөгөөс Би тэднийг үнс болгон хувиргаж, цаашид оршин тогтнохыг нь зөвшөөрөхгүй байсан. Гэхдээ Миний хийдэг ажил утга учиртай бөгөөд иймээс Би хүнийг яаран гэсгээдэггүй. Хүмүүс бие махбодоо үргэлж дураар нь тавьсны шалтгаан энэ юм. Тэд Миний хүслийг ажигладаггүй, харин Миний шүүлтийн ширээний өмнө Намайг дандаа хуурч мэхэлсэн. Хүмүүс маш зоригтой: Бүх “эрүүдэх хэрэгсэл” тэднийг заналхийлэх үед өчүүхэн ч давхийхгүй. Баримтуудын өмнө тэд ямар ч баримт өгөхөөр ирэх чадваргүй хэвээр үлдсэн бөгөөд Намайг зөрүүдлэн эсэргүүцэхээс өөр юу ч хийдэггүй. Бузар заваан зүйлсээ гаргаж ир гэхэд тэд Надад мөн л хоосон гараа харуулдаг—бусад нь үүнийг “жишиг” болгон ашиглахгүй байж яаж чадах билээ? Хүмүүсийн “итгэл” “гайхан биширмээр” маш агуу учраас тэр юм.

Би Өөрийн ажлыг орчлон ертөнц даяар эхлүүлсэн; орчлон ертөнцийн хүмүүс гэнэт сэрж, гол цөмийг буюу Миний ажлыг тойрон хөдөлдөг бөгөөд Намайг тэдний дунд “аялах” үед бүгд Сатаны хүлээсээс зугтаж, Сатаны гай зовлон дунд тарчлахгүй. Миний цаг үе ирсэн учраас хүмүүс аз жаргалаар дүүрч, тэдний зүрх сэтгэл дэх уй гашуу арилж, тэнгэрт буй уйтгар гунигийн үүл агаарт хүчилтөрөгч болон хувирч, тэнд хөвдөг бөгөөд энэ мөчид Би хүнтэй хамт байхын жаргалыг эдэлдэг. Хүний үйлдэл Надад амтлах зүйл өгсөн, тиймээс Би гомдохоо больсон. Миний өдөр ирснийг дагаад газар дээрх амьтай зүйлс өөрсдийн оршин тогтнолын үндсийг дахин олж авч, газар дээрх бүх зүйл дахин сэргэсэн бөгөөд тэд Намайг өөрсдийн оршин тогтнолын үндэс гэж үздэг, учир нь Би бүх зүйлийг амиар гэрэлтэхэд хүргэж, бас тэдгээрийг чимээгүйхэн алга болоход хүргэдэг. Тиймээс бүх зүйл Миний амнаас гарах тушаалыг хүлээдэг бөгөөд Миний хэлдэг, хийдэг зүйлд баярладаг. Бүх зүйлийн дундаас Би бол Хамгийн Дээд нь—гэсэн ч Би бас бүх хүний дунд амьдарч, хүний үйл хэргийг Өөрийн бүтээсэн тэнгэр газрын илрэл болгон ашигладаг. Хүмүүс Миний өмнө агуу магтаал хэлэхэд Би бүх зүйлийн дунд өргөмжлөгддөг, тиймээс газар дээрх цэцэгс халуун нарны дор улам илүү үзэсгэлэнтэй болж, өвс илүү ногоорон, тэнгэрийн үүлс улам илүү цэнхэр харагддаг. Миний дуу хоолойноос болж хүмүүс ийш тийшээ гүйдэг; өнөөдөр Миний хаанчлалд буй хүмүүсийн нүүр царай баяр хөөрөөр дүүрч, тэдний амь өсдөг. Би Өөрийн сонгосон бүх хүний дунд ажилладаг бөгөөд Миний ажил хүний үзэл санаагаар бузартахыг зөвшөөрдөггүй, учир нь Би Өөрийн ажлыг биечлэн хэрэгжүүлдэг билээ. Намайг ажиллах үед тэнгэр, газар, тэдгээр дэх бүх зүйл өөрчлөгдөж, шинэчлэгддэг бөгөөд Намайг ажлаа дуусгах үед хүн бүрмөсөн шинэчлэгдэж, Миний хүссэн зүйлийн үрээр зовуурьтай амьдрахаа больдог, учир нь аз жаргалын дуу чимээ газар дэлхий даяар сонсогдож, Би энэ боломжийг ашиглан хүнд өгөх Өөрийн ерөөлийг хайрладаг билээ. Намайг хаанчлалын Хаан байхад хүмүүс Надаас эмээдэг ч Намайг хүмүүсийн дунд Хаан байж, хүмүүсийн дунд амьдарч байхад хүмүүс Надаас ямар ч баяр хөөр олдоггүй, учир нь Миний талаарх тэдний үзэл хэтэрхий ноцтой агаад арилгахад хэцүү маш гүн шингэсэн байдаг. Хүний

илэрхийллийн улмаас Би Өөрийн тохиромжтой ажлыг хийдэг бөгөөд Би тэнгэр өөд өндөрт өгсөж, Өөрийн уур хилэнг хүн дээр буулгахад Миний талаарх хүмүүсийн янз бүрийн санал бодол тэр даруй үнс болон хувирдаг. Миний талаарх өөр хэдэн үзлээ ярь гэж Би тэднээс асуудаг боловч тэдэнд юу ч байхгүй мэт, тэд даруухан мэт мэл гайхдаг. Би хүмүүсийн үзэлд хэдий чинээ их амьдарна, тэд Намайг төдий чинээ их хайрладаг бөгөөд Би хүмүүсийн үзлийн гадна хэдий чинээ амьдарна, тэд Надаас төдий чинээ их холдож, Миний талаар илүү их санал бодолтой болдог, учир нь Би дэлхийг бүтээсэн цагаас өнөөг хүртэл Би хүмүүсийн үзэлд үргэлж амьдарч ирсэн юм. Өнөөдөр хүмүүсийн дунд ирэхдээ Би хүмүүсийн бүх үзлийг арилгана, иймээс хүмүүс үүнээс зүгээр л татгалздаг—гэсэн ч тэдний үзэлтэй харьцах тохиромжтой арга барил Надад бий. Хүмүүс санаа зовж, эсвэл түгших ёсгүй; Би Өөрийн аргаар бүх хүн төрөлхтнийг аварч, бүх хүнээр Өөрийгөө хайрлуулж, тэнгэр дэх Миний ерөөлийг эдлэх боломжийг тэдэнд олгоно.

1992 оны 4 дүгээр сарын 17

34-Р БҮЛЭГ

Би нэгэнтээ хүнийг Өөрийнхөө гэрт зочноор урьсан боловч түүнийг зочин мэт урихын оронд Би түүнийг цаазын тавцанд аваачсан мэт Миний дуудлагын улмаас тэр нааш цааш гүйсэн. Тиймээс Миний гэр хоосон үлдсэн, учир нь хүн үргэлж Надаас зайлсхийж, үргэлж Надаас сэрэмжилж байсан. Энэ нь Намайг Өөрийн ажлын нэг хэсгийг хэрэгжүүлэх аргагүй болгосон юм, өөрөөр хэлбэл, Би түүнд зориулан бэлдсэн идээ ундаа хураасан, учир нь хүн энэ идээ ундыг амсахыг хүсээгүй, тиймээс Би түүнийг ид гэж албадаагүй. Гэтэл хүн өлсгөлөнд нэрвэгдсэнээ гэнэт мэдээд ирж, Миний тусламжийг гуйн Миний хаалгыг тогшдог—түүнийг тийм их гачигдалтай байгааг хараад Би түүнийг аврахгүй байж яахан чадах билээ? Тиймээс Би хүнд идүүлэхийн тулд дахиад идээ унд бэлддэг ба зөвхөн тэгэхэд л тэр Миний хэчнээн гайхан биширмээр болохыг мэдэрдэг, тиймээс тэр Надад найдаж эхэлдэг юм. Түүнд хандах Миний хандлагын дүнд тэр аажмаар Намайг “эргэлзэж тээнэгэлзэлгүй” хайрлах болдог ба Би түүнийг “чандарлах газар” илгээх болно гэж сэжиглэхээ больдог, учир нь энэ бол Миний хүсэл биш билээ. Иймээс Миний зүрх сэтгэлийг харсныхаа дараа л хүн Надад үнэхээр найддаг, энэ нь түүний хэр “хашир” болохыг харуулдаг. Гэсэн ч Би заль мэхнийх нь улмаас хүнээс болгоомжилдоггүй, харин Өөрийн халуун дулаан тэврэлтээр хүний зүрх сэтгэлийг уяраадаг. Энэ нь Миний одоо хийж байгаа зүйл биш гэж үү? Энэ нь одоогийн үе шатанд хүмүүст илэрхийлэгдэж байгаа зүйл биш гэж үү? Яагаад тэд тийм зүйлс хийхдээ чадамгай байдаг юм бэ? Яагаад тэд тийм сэтгэлтэй байдаг юм бэ? Тэд Намайг үнэхээр мэддэг учраас тэр үү? Тэдэнд Намайг гэсэн хэмжээ хязгааргүй хайр үнэхээр байдаг

учраас тэр үү? Би хэнийг ч Намайг хайрла гэж албаддаггүй, харин зүгээр л тэдэнд сонголтоо хийх эрх чөлөөг өгдөг; үүнд Би хөндлөнгөөс оролцдоггүй, мөн хувь заяаныхаа талаар сонголт хийхэд нь тэдэнд тусалдаггүй. Хүмүүс Миний өмнө шийдвэрээ гаргасан, тэд Надаар шалгуулахаар үүнийгээ Миний өмнө авчирсан ба “хүний шийдвэрийг” агуулсан цүнхийг онгойлгоод дотор нь замбараагүй холилдсон ч нэлээд “арвин” зүйлс байхыг нь харсан. Хүмүүс Намайг бүлтийн харж, Би өөрсдийнх нь шийдвэрийг хамж нэг тийш болгоно гэдгээс ихэд айж байсан. Гэхдээ хүний сул талын улмаас бүр анхандаа Би шүүлт хийгээгүй, харин цүнхийг нь хаагаад хийх ёстой ажлаа үргэлжлүүлэн хийсэн юм. Гэсэн хэдий ч хүн Миний ажлын араас Миний удирдамжид ороогүй, харин түүний шийдвэр Надаар магтагдсан эсэх талаар санаа зовсоор байсан. Би маш их ажил хийсэн, маш их үг хэлсэн боловч өнөөг хүртэл хүн Миний хүслийг ухаарах чадваргүй хэвээр үлдсэн, тиймээс түүний будлиулмаар үйлдэл бүр нь Миний толгойг эргүүлж орхидог. Яагаад тэр үргэлж Миний хүслийг ухаарах чадваргүй, аливааг өөрийнхөө хүссэнээр яаруу сандруу хийдэг юм бэ? Түүний уураг тархи шоконд орсон юм уу? Тэр Миний хэлдэг үгсийг ойлгодоггүй байж болох уу? Тэр яагаад үргэлж урагшаа эгц харан үйлддэг боловч ирээдүйн хүмүүст зам тавьж, үлгэр жишээ үзүүлэх чадваргүй байдаг юм бэ? Петрээс өмнө үлгэр жишээ үзүүлсэн хүн байсан уу? Миний удирдамжийн дор Петр амьд үлдсэн биш гэж үү? Яагаад өнөөдрийн хүмүүс үүнийг хийх чадваргүй байдаг юм бэ? Дагах үлгэр жишээтэй болчхоод яагаад Миний хүслийг хангаж чадахгүй хэвээр байдаг юм бэ? Хүн Надад итгэдэггүй хэвээр гэдгийг энэ нь харуулдаг ба өнөөдрийн золгүй нөхцөл байдалд хүргэсэн зүйл энэ юм.

Тэнгэрт нисэж буй бяцхан шувуудыг ажиглахдаа Би баярладаг. Хэдий тэд Миний өмнө шийдвэрээ гаргаагүй, Намайг “хангах” ямар ч үггүй байдаг боловч Миний тэдэнд өгсөн дэлхий ертөнцөөс тэд жаргал цэнгэл олдог. Гэвч хүн ингэх чадваргүй бөгөөд царай нь уй гансралаар дүүрэн байдаг—Би түүнд төлж болшгүй өртэй байж болно гэж үү? Яагаад түүний царайд үргэлж нулимсны мөр байдаг юм бэ? Би толгодод цэцэглэх сараана цэцэгсийг бахдан биширдэг. Цэцэгс болон зүлэг налуу газрыг бүрхдэг, харин хавар айлчлан ирэхээс өмнө сараана цэцэг, газар дээрх Миний алдарт өнгө нэмдэг—хүн ийм юм хийж чадах уу? Намайг эргэн ирэхээс өмнө газар дээр Надад гэрчилж чадсан уу? Агуу улаан лууны улс оронд тэр Миний нэрийн төлөө өөрийгөө зориулж чадах юм уу? Миний айлдварууд хүнд хандах шаардлагуудаар нэвчсэн мэт байдаг—эдгээр шаардлагын улмаас тэр Надад зэвүүцдэг; түүний бие хэтэрхий сул дорой учраас, мөн үндсэндээ Миний шаардсан зүйлд хүрэх чадваргүй учраас тэр Миний үгээс айдаг. Намайг амаа ангайхад газар дээрх хүмүүс гай гамшгаас зугтахаар оролдож буй мэт зүг бүрд дүрвэж байгааг Би хардаг. Намайг царайгаа халхлахад, Намайг биеэрээ эргэхэд хүмүүс нэн даруй сандралд автдаг. Тэд юу хийхээ мэддэггүй, учир нь тэд Намайг явахаас айдаг; тэдний үзлээр Миний явах өдөр бол тэнгэрээс гай гамшиг бууж ирэх өдөр, тэдний шийтгэл эхлэх өдөр байдаг. Гэсэн ч Миний хийдэг зүйл хүний үзлийн

яг эсрэг байдаг; Би хэзээ ч хүний үзлийн дагуу үйлдээгүй, хүний үзэл Надтай нийцэхийг хэзээ ч зөвшөөрөөгүй. Миний ажиллах цаг бол хүнийг илчлэх яг тэр үе юм. Өөрөөр хэлбэл, Миний үйлдлийг хүний үзлээр хэмжиж болохгүй. Бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэл хэн ч Миний хийдэг зүйлээс “шинэ тив” олж илрүүлээгүй, хэн ч Миний үйлддэг хуулиудыг ухаараагүй, хэн ч шинэ зам нээгээгүй. Тиймээс өнөөдөр хүмүүс зөв замд орох чадваргүй үлдсэн—энэ нь яг тэдэнд дутагддаг зүйл бөгөөд тэдний орох учиртай зүйл юм. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Би өмнө нь хэзээ ч ийм төсөл эхлүүлээгүй, Би зүгээр л эцсийн өдрүүд дэх Өөрийн ажилд хэдэн шинэ хэсэг нэмсэн. Гэсэн ч тийм ойлгомжтой нөхцөл байдалд хүмүүс Миний хүслийг мөн л ухаарах чадваргүй байдаг—энэ нь яг тэдэнд дутагддаг зүйл биш гэж үү?

Шинэ ажилд орсны дараа Надад хүнд тавих шинэ шаардлага байна. Өнгөрсөн үеийн шаардлагууд хүнд ямар ч үр нөлөөгүй мэт байдаг, тийм учраас тэдгээрийг мартдаг. Миний ажилладаг шинэ арга барил юу вэ? Би хүнээс юу шаарддаг вэ? Урьд хийсэн зүйл нь Миний хүслийн дагуу байсан эсэхийг, тэдний үйлдлүүд нь Миний шаардсан хил хязгаар дотор байсан эсэхийг хүмүүс өөрсдөө хэмжиж үнэлж чадна. Би бүхнийг нэг бүрчлэн шалгах хэрэггүй; тэд өөрсдийн биеийн хэмжээг ухаарсан, иймээс оюун санаандаа ямар хэмжээнд үйлдэж болох талаар мэддэг, Би тэдэнд нарийн тодорхой хэлэх хэрэггүй. Намайг ярих үед зарим хүн бүдэрч магадгүй; тиймээс Би улмаар хүмүүсийг сул дорой болохоос сэргийлэхийн тулд Өөрийн үгийн энэ хэсгийг хэлэхээс зайлсхийсэн. Энэ нь хүний эрэл хайгуулд илүү их ашиг тустай биш гэж үү? Энэ нь хүний ахиц дэвшилд илүү их ашиг тустай биш гэж үү? Өнгөрснөө мартаж, урагш тэмүүлэхийг хүсдэггүй хэн байна вэ? Өөрийн “бодлогогүй байдлын” улмаас Би, Миний ярьдаг арга барил аль хэдийн шинэ хүрээнд орсныг хүмүүс ойлгож байгаа эсэхийг мэдэхгүй байна. Түүнээс гадна, Миний ажил Намайг их “завгүй” байлгадаг болохоор Миний ярианы өнгийг хүмүүс ойлгож байгаа эсэхийг асууж лавлах цаг Надад байхгүй. Тиймээс Надад арай илүү ойлгоцтой хандахыг л Би хүмүүсээс гуйдаг. Миний ажил Намайг маш “завгүй” байлгадаг учраас Би хүмүүсийг удирдан чиглүүлэхийн тулд Өөрийн ажлын баазуудад биечлэн очиж чаддаггүй ба иймд Би тэдний талаар “бага зэргийн ойлголттой” байдаг. Дүгнэн хэлбэл, өөр юу ч байсан Би одоо шинэ эхлэлд болон шинэ арга барилд албан ёсоор ороход нь хүнийг хөтөлж эхэлсэн. Миний хэлдэг зүйлд алиа байдал, хошигнол болон ялангуяа нэн хүчтэй егөөдлийн өнгө аяс байгааг хүмүүс Миний бүх айлдваруудаас харсан. Тиймээс хүн, бид хоёрын хоорондын эв зохицол өөрийн эрхгүй эвдэрч, хүмүүсийн нүүр царайг өтгөн үүл бүрхэхэд хүргэсэн. Гэхдээ Би үүгээр хязгаарлагдаагүй, харин Өөрийн ажлыг үргэлжлүүлдэг, учир нь Миний хэлдэг, хийдэг бүхэн бол Миний төлөвлөгөөний чухал хэсэг; Миний амнаас гарсан үг бүхэн хүнд тусладаг бөгөөд Миний хийдэг юу ч ялимгүй жаахан биш; Миний хийдэг бүхэн бүх хүнд сургамжтай билээ. Хүнд дутагддаг болохоор л Би биеэ барилгүй яриад л байдаг. Зарим хүн Намайг шинэ

шаардлага тавихыг цөхрөлтгүй хүлээж байж магадгүй. Хэрвээ тийм бол Би тэдний хэрэгцээг хангана. Гэхдээ Би нэг зүйлийг та нарт сануулах ёстой: Ярих үедээ Би хүмүүс илүү их мэдлэг ухаан олж авна гэж найддаг. Тэд илүү ажигч гярхай болж, ингэснээр Миний үгээс илүү ихийг олж аваад Миний шаардлагуудыг биелүүлнэ гэж Би найддаг. Өмнө нь чуулганд хүмүүсийн төвлөрдөг зүйл нь харьцуулж, эвдэгдэх явдал байсан. Миний үгийг идэж, уух нь тэдгээрийн зорилго, эх сурвалжийг ойлгох суурин дээр хийгддэг байсан—гэхдээ өнөөдөр өнгөрсөн үетэй адилгүй, Миний айлдваруудын эх сурвалжийг ухаарах чадвар хүмүүст огт байдаггүй тул Надаар харьцуулж, эвдэгдэх ямар ч боломж тэдэнд байхгүй, учир нь тэд Миний үгийг идэж, уух төдийхөнд бүх хүч чармайлтаа зориулдаг. Гэхдээ эдгээр нөхцөл байдлын дор хүртэл тэд Миний шаардлагыг хангах чадваргүй хэвээр үлдсэн ба иймээс Би тэдэнд шинэ шаардлага тавьдаг: Би тэднээс Надтай хамт шалгалтад ор, гэсгээлтэд ор гэж шаарддаг. Гэхдээ Би та нарт нэг зүйлийг сануулъя: Энэ нь хүнийг үхүүлэх гэсэн явдал биш, харин Миний ажлын шаарддаг зүйл, учир нь одоогийн үе шатанд Миний үг хүнд хэтэрхий ойлгогдошгүй бөгөөд хүн Надтай хамтран ажиллах чадваргүй—ямар ч аргагүй! Би хүнийг Өөртэйгөө хамт шинэ арга барилд оруулж л чадна. Өөр юу хийх юм бэ? Хүний дутагдлуудын улмаас Би ч бас хүний ордог урсгалд орох ёстой—Би хүмүүсийг төгс болгодог Нэгэн биш гэж үү? Би энэ төлөвлөгөөг гаргасан Нэгэн биш гэж үү? Хэдийгээр өөр шаардлага нь хэцүү биш боловч эхнийхээсээ хоёрдугаар зэргийнх биш. Эцсийн өдрүүдийн бүлэг хүмүүсийн дундах Миний ажил бол урьд өмнө үзэгдээгүй төсөл бөгөөд тиймээс Миний алдар сансар огторгуйд түгж, бүх хүн Миний төлөө сүүлчийн зовлон бэрхшээлийг туулах ёстой. Та нар Миний хүслийг ойлгож байна уу? Энэ бол хүнд тавих Миний эцсийн шаардлага, өөрөөр хэлбэл, бүх хүн агуу улаан лууны өмнө Миний төлөө цуурайтсан гэрчлэл хийж, өөрсдийгөө Надад сүүлчийн удаа өргөн барьж, эцсийн удаа Миний шаардлагыг хэрэгжүүлж чадна гэж Би найдаж байна. Та нар үнэхээр үүнийг хийж чадах уу? Та нар өнгөрсөн үед Миний зүрх сэтгэлийг хангалуун болгох чадваргүй байсан—та нар эцсийн удаа энэ хэв маягийг эвдэж чадах уу? Би хүмүүст эргэцүүлэх боломж олгодог; Надад хариулт өгөхөөс нь өмнө Би тэднээр анхааралтай тунгаан бодуулдаг—ингэх нь буруу юу? Би хүний хариултыг хүлээж, түүний “хариу захиаг” хүлээдэг—Миний шаардлагыг биелүүлэх итгэл та нарт байна уу?

1992 оны 4 дүгээр сарын 20

35-Р БҮЛЭГ

Надтай хамт нэг урсгалд амьдрах боломжийг хүмүүст олгож, хүмүүсийн дунд Би Өөрийн ажлыг хийж эхэлсэн. Би Өөрийн ажлыг дуусгахдаа бас л хүмүүсийн дунд байх болно, учир нь тэд бол Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний турш

удирдуулдаг бөгөөд тэднийг бүх зүйлийн эзэд болгох нь Миний хүсэл билээ. Энэ шалтгааны учир Би хүмүүсийн дунд алхсаар байдаг. Миний ажлын хурд нэмэгдсэн учраас Би хүн төрөлхтөнтэй хамт одоогийн эринд ороходоо сэтгэл маш тайван байна. Хүмүүс хэрхэн мөр зэрэгцэн алхаж чадах вэ? Би мэдрэмжгүй, мангуу хүмүүс дээр маш их ажил хийсэн боловч тэд Намайг нандигнан хайрладаггүй учраас юу ч олж аваагүй. Би бүх хүний дунд оршиж, тэдний хөдөлгөөн бүрийг хаана ч байхад нь, газар дээр ч, доор ч аль алин дээр нь ажигласан. “Хүмүүс” гэж ангилагддаг бүхэн “Намайг эсэргүүцэх” нь тэдний ажил юм шиг, энэ ажлыг хийхгүй бол тэд хэн ч өргөж аваагүй тэнэмэл өнчид болчих юм шиг л Намайг эсэргүүцэж байна. Гэсэн хэдий ч хүмүүсийн үйлдэл болон зан байдалд үндэслэн Би тэдэнд дур зоргоороо ял оногдуулдаггүй. Харин Би тэдний биеийн хэмжээнд нийцүүлэн тэднийг дэмжиж, хангадаг. Хүн бол Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний гол дүр учраас “хүн” хэмээх дүрд тоглогчдод Би илүү их удирдамж өгдөг, ингэснээр тэд уг дүрд үнэн сэтгэлээсээ, чадлынхаа хэрээр тоглох ба ингэснээр Миний найруулж буй энэ жүжиг сэтгэл хөдөлгөм амжилттай болох юм. Энэ нь хүн төрөлхтөнд тавих Миний хүсэлт юм. Би хүн төрөлхтний төлөө залбираагүй бол тэд дүрдээ тоглож чадахгүй байх уу? Тэгвэл хүмүүсийн Надаас хүсдэг зүйлийг Би биелүүлж чадна, гэхдээ Миний тэднээс хүсдэг зүйлийг тэд биелүүлж чадахгүй байх уу? Би хүмүүсийг дарлах гээд сүр хүчээ ашигладаггүй гэхэд болно. Харин ч энэ бол тэднээс Би бүр үнэн зүрхнээсээ, чин сэтгэлээсээ гуйж байгаа Миний эцсийн хүсэлт юм. Тэд Миний гуйсан зүйлийг үнэхээр хийж чадахгүй гэж үү? Би хүмүүст олон жилийн турш өгсөөр ирсэн боловч хариуд нь юу ч аваагүй. Хэзээ нэгэн цагт хэн Надад ямар нэгэн зүйлийг өгсөн бэ? Миний цус, хөлс, нулимс зүгээр л уулын будан шиг гэж үү? Би хүмүүст олон удаа “урьдчилан сэргийлэх тарилга” өгч, тэдэнд тавих Миний шаардлага хатуу чанд биш гэдгийг хэлсэн. Тэгвэл яагаад хүмүүс Надаас байнга зайлсхийдэг юм бэ? Би тэднийг баригдмагцаа алагдах ангаахай шиг үзэж хандана гээд тэр үү? Би үнэхээр тийм харгис, өрөвч сэтгэлгүй гэж үү? Хүмүүс Намайг үргэлж өөрсдийнхөө үзлээр хэмждэг. Тэдний үзэлд байдаг Би тэнгэрт байдаг Би хоёр адилхан юм уу? Би хүмүүсийн үзлийг Өөрийн зугаа цэнгэлийн бай гэж үздэггүй. Харин ч Би тэдний зүрх сэтгэлийг үнэлүүштэй зүйл гэж хардаг. Гэсэн хэдий ч Би тэдний мөс чанарт нэлээд эгдүүцдэг, учир нь тэдний хэлдгээр Надад тэр нь байдаггүй. Тиймээс тэдний мөс чанарын тухай Надад хэдэн илүү үзэл бодол байна. Гэсэн хэдий ч Би тэдний мөс чанарыг шууд шүүмжлэхээс татгалздаг; үүний оронд Би тэднийг тэвчээр, арга дүйгээр залж чиглүүлдэг. Эцсийн эцэст хүмүүс сул дорой бөгөөд ямар ч ажил хийж чаддаггүй.

Өнөөдөр Би хэмжээ хязгааргүй гэсгээлтийн ертөнц рүү албан ёсоор алхан орсон бөгөөд үүнийг хүн төрөлхтөнтэй зэрэгцэн баясаж байна. Би мөн гараараа тушаал гаргаж, хүн төрөлхтөн Миний тушаал дор томоотой байдаг; Намайг хэн ч эсэргүүцэж зүрхэлдэггүй. Бүгд Миний удирдамж дор Миний даалгасан үүргийг биелүүлж байна, учир нь энэ бол тэдний “ажил” юм. Тэнгэр дэх болон тэнгэр доорх

бүх зүйлийн дундаас хэн Миний төлөвлөгөөнд захирагддаггүй вэ? Хэн Миний хяналтад байдаггүй вэ? Хэн Миний үг болон ажлын төлөө магтаал, сайшаал хэлдэггүй вэ? Хүмүүс Миний үйл хэрэг болон үйлдлүүдийг гайхан биширдэг, тэгээд Миний хөдлөл бүрийн дүнд өөрсдийгөө Миний ажлын урсгалд оруулдаг. Хэн гаргаж чадах юм бэ? Хэн Миний зохицуулсан ажлаас зугтаж чадах юм бэ? Миний захиргааны зарлигаар хүмүүсийг албадан үлддэг; үүнгүйгээр тэд бүгд “тэргүүн шугамаас” сэмхэн хойшоо явж, “оргодлууд” болох байсан юм. Үхлээс айдаггүй хэн байна вэ? Хүмүүс үнэхээр биеэ золиосолж чадах уу? Би хүний уг чанарын талаар аль эрт бүрэн гүйцэд ойлголттой болсон болохоор Би хэнийг ч шахдаггүй. Тиймээс Би хүмүүсийн хэзээ ч хийж байгаагүй төслүүдийг үргэлж хийж ирсэн билээ. Хэн ч Миний ажлыг хийж чадахгүй учраас Сатантай үхэх сэхэхээ үзэх тулалдаанд орохын тулд Би тулааны талбарт биечлэн хөл тавьсан юм. Өнөөдөр Сатан туйлын эрээ цээргүй байна. Өөрийн ажлын гол хэсгийг гайхуулж, Өөрийн агуу хүч чадлыг илчлэхийн тулд Би энэ боломжийг яагаад ашиглахгүй байх билээ? Урьд нь Миний хэлсэнчлэн Би Сатаны ов мэхийг Өөрийн товойлгогч болгон ашигладаг; энэ нь дээд зэргийн боломж биш гэж үү? Одоо л Би тааламжтай инээмсэглэлийг харуулдаг, учир нь Би Өөрийнхөө зорилгод хүрсэн билээ. Би цаашид ийш тийшээ гүйж, хүмүүсээс “тусламж” гуйхгүй. Би тэвдэн сандрахаа больсон ба цаашид тэнүүлчийн амьдралаар амьдрахгүй. Одоогоос эхлээд Би амар тайван амьдрах болно. Хүмүүс ч мөн адил эсэн мэнд, эрүүл саруул байх болно, учир нь Миний цаг үе ирсэн. Газар дээр Би хүний завгүй амьдрал буюу олон шударга бус явдал тохиолдсон мэт санагддаг амьдралаар амьдарсан. Хүмүүсийн үзэхэд, Би тэдний баяр хөөр, уй гашууг, мөн түүнчлэн тэдний золгүй явдлыг хуваалцсан. Хүмүүсийн адилаар Би ч бас газар дээр, тэнгэрийн дор амьдарсан. Тиймээс тэд Намайг үргэлж бүтээгдсэн зүйл шиг үзсэн. Хүмүүс Намайг тэнгэрт байдгаар минь хараагүй учраас Миний ашиг сонирхлын тулд хэзээ ч нэг их хичээл зүтгэл гаргаагүй. Гэсэн хэдий ч өнөөдрийн нөхцөл байдалд хүмүүс Намайг өөрсдийнх нь хувь заяаны Эзэн бөгөөд үүлнээс илтгэдэг илтгэгч гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Тийм учраас л хүмүүс Миний өмнө шүтэн мөргөж, толгойгоо газарт хүргэсэн юм. Энэ нь Миний ялгуусан эргэн ирэлтийн баталгаа биш гэж үү? Энэ нь бүхий л дайсагнасан хүчийг дийлсэн Миний ялалтын дүр зураг биш гэж үү? Дэлхий төгсгөлдөө ирж байгаа ба хүн төрөлхтөн асар их цэвэрлэгээ туулна гэдэг зөн бүх хүнд байсан. Гэсэн хэдий ч Миний тэднээс хүссэн зүйлийг тэд ухамсартайгаар хийж үнэндээ чаддаггүй, иймээс тэд Миний гэсгээлтийн дор цурхиран уйлахаас өөр аргагүй. Юу хийж чадах билээ? Дуулгаваргүй бай гэж хүмүүст хэн хэлсэн бэ? Сүүлчийн эрин үед ор гэж тэдэнд хэн хэлсэн бэ? Тэд эцсийн өдрүүдэд яагаад хүний ертөнцөд төрсөн бэ? Юм нэг бүрийг Би биечлэн зохицуулж, төлөвлөдөг. Хэн гомдоллож чадах юм бэ?

Дэлхий ертөнц бүтээгдсэн үеэс эхлэн Би хүмүүсийн дунд хэсүүчилж, газар дээр оршин тогтноход нь хань болж байсан. Гэхдээ өмнөх үеийнхнээс ганц ч хүн Надаар сонгогдоогүй; Миний чимээгүй мэдлэг хүн бүхнийг няцаасан. Учир нь, өнгөрсөн

үеийн хүмүүс Надад онцгойлон үйлчлээгүй, тиймээс хариуд нь Би тэднийг онцгойлон хайрлаагүй. Тэд Сатаны “бэлгүүдийг” авсан ба дараа нь тэдгээрийг Надад хээвнэг барьсан. Энэ нь Миний эсрэг доромжлол биш байсан гэж үү? Тэднийг тахил өргөж байхад нь Би Өөрийн зэвүүцлийг харуулаагүй; оронд нь Би эдгээр “бэлгийг” Өөрийн удирдлагын эд материалуудад нэмснээр тэдний арга мэхийг Өөртөө ашигтайгаар эргүүлсэн. Хожим тэднийг машин боловсруулсны дараа Би үүссэн бүх хог хаягдлыг шатааж орхино. Эдүгээ үеийн хүмүүс Надад олон “бэлэг” өгөөгүй боловч Би тэднийг үүнийх нь төлөө зэмлэдэггүй. Энэ хүмүүс үргэлж ядуу даржин, гар хоосон байсан; тиймээс тэдний нөхцөл байдлын бодит байдлыг ажиглаад Би хүний ертөнцөд ирснээсээ хойш тэдэнд ямар нэгэн үндэслэлгүй шаардлага хэзээ ч тавиагүй. Харин тэдэнд “эд материал” өгснийхөө дараа Би зүгээр л Өөрийн хүссэн “бэлэн болсон бүтээгдэхүүнийг” хайсан, учир нь энэ бол хүн төрөлхтний хүрч чадах чинээ билээ. Би зохистой шаардлага бодож олохоосоо өмнө хүн шиг амьдрах нь юу гэсэн үг болохыг судалж, олон жилийг зовлон бэрхшээлд өнгөрүүлсэн. Би хүний амьдралыг туулаагүй байсан бол тэдний хувьд хэлэлцэхэд хэцүү байдаг хэрэг явдлуудыг Би хэрхэн ойлгож чадах билээ? Гэсэн хэдий боловч хүмүүс үүнийг ингэж үздэггүй; тэд Намайг хэмжээлшгүй хүчит, ер бусын Бурхан Өөрөө гэж хэлдэг. Энэ нь чухамдаа түүхэн турш, тэр ч бүү хэл, өнөөдөр хүртэл бүх хүний тээж явдаг үзэл биш гэж үү? Газар дээр Намайг үнэхээр бүрэн мэддэг нэг ч хүн байхгүй гэж Би хэлсэн. Энэ сануулга нь өөрийн гэсэн далд утгатай; энэ нь хоосон яриа төдий биш. Би үүнийг Өөрөө туулж, ажигласан, иймээс Надад нарийн учрын талаар ойлголт байдаг. Би хүний ертөнцөд бууж ирээгүй байсан бол Намайг мэдэх боломж хэнд байх юм бэ? Хэн Миний үгийг биечлэн сонсож чадах юм бэ? Хэн Миний биеийг өөрсдийнхөө дунд харж чадах юм бэ? Эрин үеүдийн турш Би үргэлж үүлэн дунд нуугдаж байсан. “Тэдэнд үлгэр дуурайл болохын тулд эцсийн өдрүүдэд Би хүний ертөнцөд бууж ирнэ” гэж Би эртнээс зөгнөсөн. Ийм учраас өнөөдөр хүмүүс өөрсдийн мэдлэгийн хүрээг тэлэх хувьтай юм. Энэ нь тэдэнд хайрласан Миний сайхан сэтгэл биш гэж үү? Тэд Миний нигүүлслийг огт ойлгохгүй байж болох уу? Яагаад хүмүүс ийм мэдрэмжгүй, мангуу байдаг юм бэ? Энэ хүртэл ирчихлээ; тэд яагаад бас л сэрээгүй байгаа юм бэ? Би энэ ертөнцөд олон жил байсан боловч хэн Намайг мэддэг вэ? Би хүмүүсийг гэсгээдэгт гайхах юмгүй. Тэд бол Би эрх мэдлээ хэрэгжүүлэх юмс мэт санагддаг; тэд гал нээхэд бүгд “зугтах” Миний бууны сум шиг санагддаг. Хүмүүс ийнхүү төсөөлдөг. Би хүмүүсийг үргэлж хүндэлсэн; Би хэзээ ч тэднийг боол шиг дур зоргоороо дарлан мөлжиж, эсвэл худалдаагүй. Учир нь Би тэднийг орхиж чадахгүй, тэд ч Намайг орхиж чадахгүй. Тиймээс бидний хооронд амин чухал холбоо бий болсон. Би хүнийг үргэлж нандигнан хайрласан. Харин хүн төрөлхтөн Намайг хэзээ ч нандигнан хайрлаагүй атлаа Надад үргэлж найдаж байсан нь Би тэдний төлөө хичээл чармайлтаа үргэлжлүүлэн зориулдгийн шалтгаан юм. Би хүмүүсийг Өөрийн эрдэнэс мэт хайрладаг, учир нь тэд бол газар дээрх Миний удирдлагын “үндсэн хөрөнгө” билээ;

тиймээс Би тэднийг таягдан хаяхгүй нь лавтай. Хүмүүст хандах Миний хүсэл хэзээ ч өөрчлөгдөхгүй. Тэд Миний тангарагт үнэхээр итгэж чадах уу? Тэд Миний төлөө Намайг хэрхэн хангалуун болгож чадах вэ? Энэ нь бүх хүн төрөлхтөнд зориулсан хичээл; энэ нь Миний тэдэнд өгсөн “гэрийн даалгавар” юм. Үүнийг биелүүлэхийн төлөө тэд бүгд шаргуу ажиллана гэдэг нь Миний найдвар билээ.

1992 оны 4 дүгээр сарын 23

36-Р БҮЛЭГ

Бүх зүйл Миний гараар зохицуулагддаг. Хэн хүссэнээрээ хийж зүрхлэх юм бэ? Хэн үүнийг хялбархан өөрчилж чадах юм бэ? Хүмүүс агаарт хөвж, тоос шороо хөдлөхөд хөдөлж, нүүр царай нь завааран харлаж, толгойноосоо хөлөө хүртэл үзэшгүй муухай болдог. Би сэтгэлдээ гуниг тээн үүлсийн дундаас ажигладаг: Нэгэнтээ эрч хүчээр дүүрэн байсан хүн яагаад ийм болоо вэ? Яагаад тэр үүнийг мэддэггүй, үүнд мэдрэмжгүй байдаг вэ? Яагаад тэр “өөрийгөө хайхралгүй орхиж”, бузар буртагт будагдахыг зөвшөөрдөг юм бэ? Өөрийгөө хайрлах, хүндлэх нь түүнд ийм дутмаг байгаа хэрэг юм. Яагаад хүн үргэлж Миний шаардсан зүйлээс зайлсхийдэг юм бэ? Би түүнд үнэхээр харгис, өрөвч сэтгэлгүй ханддаг гэж үү? Би үнэхээр эзэрхэг, агаад бодлогогүй гэж үү? Тэгвэл хүмүүс яагаад үргэлж Над руу цоо ширтсэн нүдээр хардаг юм бэ? Яагаад тэд үргэлж Намайг үзэн яддаг юм бэ? Би тэднийг мөхлийн замд аваачсан гэж үү? Хүн Миний гэсгээлтээс хэзээ ч, юу ч олж илрүүлээгүй, учир нь тэр хүзүүнд нь угласан буулгыг хоёр гараараа зуурахаас өөр юм хийдэггүй ба дайснаа ажиглаж байгаа юм шиг Надаас нүд салгадаггүй—зөвхөн энэ мөчид л Би түүний хэчнээн эцэнхий болохыг нь хардаг. Үүний улмаас шалгалтуудын дунд ер нь хэн ч бат зогсоогүй гэж Би хэлдэг юм. Хүний биеийн хэмжээ яг тийм байдаг биш гэж үү? “Хэмжээнийх” нь тоог Би түүнд хэлж өгөх хэрэгтэй юу? Хүний “өндөр” газарт мушгиралдан яваа бяцхан өтнийхөөс ихгүй бөгөөд түүний “цээж” могойныхтой л адил өргөнтэй. Үүгээрээ Би хүнийг голж басаагүй байна—эдгээр нь түүний биеийн хэмжээний яг зөв тоонууд биш гэж үү? Би хүнийг дорд үзсэн гэж үү? Хүн дүрсгүйтэж буй хүүхэдтэй адилхан. Түүнд бүр амьтадтай тоглох үе ч байдаг, гэхдээ тэр аз жаргалтай хэвээр үлддэг; мөн санаа тавих, зовних юмгүй яг муур шиг амьдардаг. Сүнсний чиглэлээс, эсвэл тэнгэр дэх Бурханы үүрэг ролиос болж Би газар дээрх хүмүүсийн амьдралын хэтэрсэн хэв маягаас ихэд залхдаг байж магадгүй. Шимэгч хорхойнхтой адил хүний амьдралаас болж “хүмүүний амьдрал” хэмээх үгийг сонирхох Миний “сонирхол” бага сага нэмэгдсэн бөгөөд Би хүний амьдралд арай илүү “хүндэтгэлтэй” хандах болсон. Учир нь зөвхөн хүн л утга учир бүхий амьдрал бүтээх чадвартай байхад Би ингэх чадваргүй мэт санагддаг. Иймээс Би “ууланд” хоргодохоос өөр аргагүй, учир нь Би

хүмүүсийн дунд зовлон бэрхшээл туулж, ажиглах чадваргүй билээ. Гэсэн ч хүн Намайг албаддаг—Надад ямар ч сонголт байхгүй! Би түүнтэй хамт туршлагаа нэгтгэн дүгнэж, түүний хажууд хүний амьдралыг туулан хүний зохицуулалтыг дуулгавартай дагаж л чадна. Тэнгэрт Би нэгэнтээ бүхий л хотоор аялсан ба тэнгэрийн дор Би нэгэнтээ бүх улс орноор аялсан. Гэхдээ хэн ч Намайг олж илрүүлээгүй; тэд ердөө Миний энд тэндгүй явах чимээг л сонссон. Хүмүүсийн үзлээр бол Би ул мөргүй, сүүдэр тусгалгүй ирж, буцдаг. Би тэдний зүрх сэтгэлд үл үзэгдэх шүтээн болсон мэт байдаг ч хүмүүс тэгж итгэдэггүй. Энэ бүхэн нь хүний амаар улайсан баримтууд биш байж таарах уу? Энэ мөчид гэсгээгдэх ёстой гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй хэн байна вэ? Хүмүүс баттай нотолгооны өмнө бас л бардам байж чадах уу?

Би хүмүүсийн дунд “бизнесийн хэлэлцээр” хийж, тэдний бүх ариун бус байдал болон зөв шударга бус байдлыг арчин хаядаг ба тийнхүү “боловсруулснаар” Миний зүрх сэтгэлд нийцэх хүн болж магадгүй юм. Гэсэн ч ажлын энэ үе шатанд хүний хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй, учир нь тэр үргэлж дөнгөж баригдсан загас шиг үсэрч, цовхчиж байдаг. Иймээс ямар нэгэн осол эндлээс сэргийлэхийн тулд Би баригдсан бүх “загасыг” алсан, үүний дараа загас дуулгавартай болсон бөгөөд өчүүхэн төдий ч гомдол гаргаагүй. Надад хүн хэрэгтэй байх үед тэр үргэлж нуугдсан байдаг. Тэрээр хэзээ ч гайхмаар дүр зураг үзээгүй юм шиг, хөдөө төрөөд хотын хэрэг явдлын талаар юу ч мэддэггүй юм шиг байдаг. Би хүний дутагдаж байгаа хэсэгт Өөрийн мэргэн ухааныг нэмж, Намайг мэдэхэд түүнийг хүргэдэг; хүн хэтэрхий ядуу болохоор Би хүмүүсийн дунд биечлэн ирж, түүнд “эд баялагт хүрэх замыг” өгч, түүнийг нүдээ нээхэд хүргэдэг юм. Үүгээрээ Би түүнийг аварч байгаа биш гэж үү? Энэ нь хүнийг гэсэн Миний энэрэл биш гэж үү? Хайрыг болзолгүйгээр өгч байгаа юу? Тэгвэл гэсгээлт нь үзэн ядалт уу? Би хүнд өөр өөр өнцгөөс тайлбарласан боловч тэр үүнийг үг, хоосон сургаал мэт л үздэг. Миний айлдваруудыг авах танаггүй гологдол эд юм шиг гар дамжуулан зардаг. Тиймээс уулын тосгоныг залгихаар асар хүчтэй шуурга ирж явна гэж Намайг хэлэхэд хэн ч үгийг минь анзаардаггүй, зөвхөн цөөхөн хүн л гэрээ нүүлгэдэг ба зүрх сэтгэлд нь эргэлзээ байдаг. Үлдсэн хэсэг нь хэнэггүй юм шиг нүүдэггүй, Би тэнгэрийн хараацай юм шиг—тэд Миний хэлсэн зүйлээс юу ч ойлгодоггүй. Зөвхөн уулс нурж, газар цууран хагарахад л хүмүүс Миний үгийн талаар бодож, зөвхөн тэр үед л тэд зүүднээсээ сэрдэг боловч тэр цаг аль хэдийн ирсэн байдаг ба тэд асар их үерт автаж, цогцсууд нь усны гадарга дээр хөвж байдаг. Дэлхий дээрх гаслан зовлонг хараад Би хүний золгүй явдлын төлөө шүүрс алддаг. Би хүний хувь заяаны төлөө их цаг зарцуулж, асар их төлөөс төлсөн. Хүмүүсийн санахад, Надад нулимсны суваг байдаггүй—харин Би, нулимсны суваггүй энэ “гажиг этгээд” нь хүний төлөө их нулимс урсгасан юм. Гэсэн хэдий ч хүн энэ талаар юу ч мэддэггүй, Би оршин байдаггүй юм шиг л гартаа байгаа тоглоомоор газар дээр тоглож байдаг. Тиймээс өнөөдрийн нөхцөл байдалд хүмүүс хөндий хүйтэн, маанаг хэвээр үлдсэн; тэд

агуйдаа хэвтсээр байгаа юм шиг байшингийн хонгилд “хөлдүү” хэвээр байдаг. Хүний үйлдлийг харахад Миний цорын ганц сонголт бол орхин явах юм…

Хүмүүсийн үзэхэд, Би хүнд сайн их зүйл хийсэн, тиймээс тэд Намайг өнөө үеийн үлгэр дуурайл гэж үздэг. Гэсэн ч тэд Намайг хүний хувь заяаг Бүрэн Захирагч, бүх зүйлийн Бүтээгч гэж хэзээ ч үзээгүй юм. Тэд Намайг ойлгодоггүй юм шиг л байдаг. Хэдийгээр хүмүүс нэгэнтээ “Ойлголт мандтугай” хэмээн хашхирсан боловч “ойлголт” хэмээх үгийг задлан шинжлэхэд хэн ч их цаг зарцуулаагүй бөгөөд хүмүүст Намайг хайрлах хүсэл байхгүй гэдгийг энэ нь харуулдаг. Өнөө үед хүмүүс Намайг хэзээ ч эрхэмлээгүй, тэдний зүрх сэтгэлд Би зай эзэлдэггүй. Тэд ирж буй зовлонгийн өдрүүдэд Намайг гэсэн жинхэнэ хайрыг харуулж чадах уу? Хүний зөв шударга байдал хэлбэр дүрсгүй зүйл буюу харж, эсвэл хүрч болохгүй зүйл хэвээр үлдсэн. Миний хүсдэг зүйл бол хүний зүрх сэтгэл, учир нь хүний биед зүрх хамгийн эрхэм нандин нь билээ. Миний үйл хэргийг хүний зүрх сэтгэлээр хариулахад тохирохгүй юм уу? Яагаад хүмүүс Надад зүрх сэтгэлээ өгдөггүй юм бэ? Яагаад тэдгээрийгээ тавьж явуулах дургүй, үргэлж цээжиндээ нааж байдаг юм бэ? Хүний зүрх сэтгэл хүмүүсийн амьдралын турш амар тайван, аз жаргалыг баттай болгож чадах уу? Намайг шаардлага тавихад хүмүүс яагаад үргэлж газраас шороо атгаж аваад Над руу шиддэг юм бэ? Энэ нь хүний зальжин арга мэх үү? Тэд хаашаа ч явах газаргүй явуулын хүнийг залилж, гэртээ хуурч аваачаад увайгүй аашлан тэднийг хөнөөхөөр оролдож буй мэт байдаг. Хүмүүс Надад бас тийм зүйл хийхийг хүссэн. Тэд нүдээ ч цавчилгүйгээр хэн нэгнийг хөнөөх зандалчин шиг, хүмүүсийг алах нь өөрсдийнх нь хоёрдогч уг чанар болсон диаволуудын хаан шиг байдаг. Гэхдээ одоо хүмүүс Миний өмнө ирж, тийм аргуудыг ашиглахыг хүссэн хэвээр байдаг—тэдэнд өөрсдийн төлөвлөгөө байхад Надад Өөрийн сөрөг арга хэмжээ байдаг. Хэдийгээр хүмүүс Намайг хайрладаггүй ч энэ удаа Би Өөрийн сөрөг арга хэмжээг олон нийтэд мэдэгдэхгүй байж яаж чадах юм бэ? Надад хүнийг залуурдах цаглашгүй, хэмжээлшгүй ур чадвар байдаг; түүний хэсэг бүрийг Би биечлэн залуурддаг бөгөөд биечлэн боловсруулдаг. Эцэстээ Би хайртай зүйлээсээ хагацах шаналлыг хүнд амсуулж, түүнийг Өөрийн зохицуулалтанд захирагддаг болгох ба тэр үед хүмүүс юуны талаар гомдоллох юм бэ? Миний хийдэг бүхэн хүний төлөө байдаггүй гэж үү? Өнгөрсөн цаг хугацаанд Би Өөрийн ажлын алхмуудын талаар хүнд хэзээ ч хэлж байгаагүй—харин өнөөдөр өнгөрсөнтэй адилгүй цаг үед Миний ажлын агуулга өөр учраас үүнээс болж тэднийг унахаас сэргийлэхийн тулд Би Өөрийн ажлын тухай хүмүүст урьдчилж хэлсэн. Энэ нь Миний хүнд хийсэн урьдчилан сэргийлэх тарилга биш гэж үү? Ямар нэгэн шалтгааны улмаас хүмүүс Миний үгийг хэзээ ч нухацтай авч үзээгүй; тэдний гэдэс өлсгөлөн бөгөөд тэд идэх юм голдоггүй, энэ нь тэдний ходоодыг муутгасан юм шиг байдаг. Гэхдээ хүмүүс өөрсдийн “эрүүл бие хааг” хөрөнгө хэмээн үзэж, “эмчийн” сэрэмжлүүлгийг хэрэгсдэггүй. Тэдний хэнэггүй байдлыг хараад Би хүний төлөө санаа зовж байгаагаа мэддэг. Хүмүүс төлөвшөөгүй бөгөөд хүний амьдралыг хараахан туулаагүй учраас

тэдэнд айдас байдаггүй; тэдний зүрх сэтгэлд “хүний амьдрал” хэмээх үг байхгүй, тэдгээрийг тоодоггүй ба Би нэг үглээ эмгэн болсон мэт Миний үгээс зүгээр л залхдаг. Товчхон хэлэхэд, ямар ч байсан хүмүүс Миний зүрх сэтгэлийг ойлгож чадна гэж Би найддаг, учир нь хүнийг үхлийн орон руу илгээх хүсэл Надад байхгүй. Энэ мөчид Миний ааш зан ямар байгааг хүн ойлгож, энэ удаа Миний үүрч байгаа ачааг анхаарч үзнэ гэж Би найдаж байна.

1992 оны 4 дүгээр сарын 26

37-Р БҮЛЭГ

Эрин үеүдийн туршид Миний хийсэн бүх ажил, тэдгээрийн үе шат бүр Миний ажилд тохирох арга барилуудыг агуулсан. Үүний улмаас Миний хайртай хүмүүс илүү ариун, Надаар ашиглагдахад илүү тохиромжтой болсон юм. Гэхдээ, үүний хажуугаар тохиолддог “азгүй зүйл” бол Миний ажлын арга барил ихсэхийн хэрээр хүмүүсийн тоо буурдаг ба энэ нь хүмүүсийг гүн эргэцүүлэлд живэхэд хүргэдэг. Мэдээж өнөөдрийн энэ ажил ч үүний нэгэн адил бөгөөд ихэнх хүмүүс дахин нэгэнтээ эргэцүүлэлд автсан; тиймээс Миний арга барил өөрчлөгдсөний улмаас орхин явахаас өөр аргагүй болох хэсэг хүмүүс байгаа. Үүнийг ийнхүү дүрсэлж болох юм: Энэ бол Миний урьдчилан тогтоосон боловч хийгээгүй зүйл юм. Бүтээлийн цаг үеэс хойш Миний ажлын арга барилын улмаас маш олон хүн унаж, олон ч хүн замаа алдсан. Гэвч хүмүүс Намайг энэрэнгүй бус эсвэл хэтэрхий хэрцгий гэж бодож байгаа эсэх нь Надад хамаагүй бөгөөд тэдний ойлголт зөв ч бай, буруу ч бай Би тэдэнд тайлбар тавихаас зайлсхийдэг. Эхлээд энэ асуудлын гол утга учрын талаар нөхөрлөцгөөе. Тэгснээр хүн бүр бүрэн ойлголттой болох боломжтой ба хүмүүс яагаад зовж буйгаа ойлгохгүй байх явдлаас сэргийлэх юм. Би хүмүүсийг хэлгүй хүн шиг чимээгүй зовж шаналахыг албадахгүй; харин ч Миний эсрэг гомдоллохоос нь сэргийлж бүхнийг тодорхой тайлбарлаж өгнө. Нэг л өдөр Би хүн бүрийн гэсгээлтээ эдэлж байхдаа чин сэтгэлээсээ магтаал хэлэх шалтгаан болно. Энэ арга барил чамд зөвшөөрч болохоор байна уу? Хүмүүсийн шаардлагад нийцэх үү?

Гэсгээлтийн цаг үеийн эхэнд Би хүмүүст энэ “цаг үеийн” ард орших ерөнхий утга учрыг эхлээд хэлж өгөх болохоор тэд Надад халдахгүй. Тухайлбал, Би хэн ч өөрчлөх учиргүй Өөрийн ажлын зохицуулалтуудыг хийх бөгөөд тэдгээрийг өөрчилсөн хэнийг ч зүгээр явуулчихгүй: тэднийг яллах болно. Үүнийг санана биз? Энэ бүгд бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Шинэ арга барилд юуны өмнө хүрэх учиртай зорилго бол өөрсдийн бодит нөхцөл байдлын талаар ойлголттой болох явдал гэдгийг бүх хүн эхлээд ойлгох ёстой. Өөрийнхөө талаар тодорхой ойлголттой болохоос өмнө чуулган дээр хамаагүй ярихыг хэнд ч зөвшөөрөхгүй ба

энэ дүрмийг зөрчсөн хүмүүсийг Би гарцаагүй гэсгээх болно. Энэ өдрөөс эхлээд бүх элчүүдийг чуулгануудад хуваарилах ба ийш тийшээ дураараа явахыг нь хориглоно—ийнхүү дураараа явах нь үр дүн багатай байна. Тэд бүгд үүргээ биелүүлж байгаа мэт харагдсан ч үнэндээ Намайг хуурч байсан. Юу ч болсон бай өнөөдөр энэ бүгд өнгөрсөн хэрэг бөгөөд дахин сөхөх ёсгүй. Үүнээс хойш, “элч” хэмээх нэр томъёог үгүй болгож, дахин хэзээ ч хэрэглэхгүй. Тэгсэнээр бүх хүн “байр сууринаасаа” бууж, өөрсдийгөө мэдэж авч болох юм. Энэ нь мэдээж тэдний авралын төлөө билээ. “Байр суурь” бол титэм биш; энэ бол ердөө л нэр цол төдий юм. Та нар Миний хэлж байгааг ойлгож байна уу? Чуулгануудыг удирддаг хүмүүс тус чуулган дотроо чуулганы амьдралаар амьдарсаар байх боловч мэдээж энэ нь хатуу чанд дүрэм биш. Шаардлагатай үед тэд хуучны бусад элч нарын хамтаар чуулгануудад айлчилж болно. Хамгийн чухал зүйл бол чуулганых нь нэг ч гишүүн үнэндээ чуулганы амьдралаар амьдрахгүй байгаа л биш бол чуулганы нөхөрлөл ихсэх ёстой. Гэсэн хэдий ч өөрсдийгөө мэдэж, агуу улаан луугийн эсрэг эсэргүүцэлд та бүгд нэгдэх ёстой гэдгийг Би цохон тэмдэглэх учиртай: Энэ бол Миний хүсэл. Хүмүүс хэр их ярих нь чухал биш; харин Миний хүмүүс бүгд нэг болон нэгдэж чадах нь хамгийн чухал бөгөөд энэ нь гэрчлэл хийх цорын ганц зам билээ. Өнгөрсөнд хүн бүр өөрсдийгөө ойлгодог болно гэж хэлж байсан, Би ч тоо томшгүй олон үг хэлсэн—харин та нар өөрсдийгөө хэр их ойлгов доо? Байр суурь нь хэдий чинээ өндөр байна, тухайн хүнд өөрийгөө хайхрахгүй байх нь төдий чинээ хэцүү байдаг. Цаашлаад, итгэл найдвар нь хэдий чинээ их байна, тэр хүн гэсгээлтийн үеэр төдий чинээ их зовох болно. Энэ бол хүн төрөлхтнийг аврах Миний аврал. Ойлгож байна уу? Үүнийг зөвхөн байгаагаар нь бүү хүлээн ав: ингэх нь хэтэрхий өнгөц, ямар ч үнэ цэнэгүй. Та нар цаад нарийн утга учрыг нь ойлгож байна уу? Хэрвээ чуулганы гишүүд үнэхээр өөрсдийгөө ойлгох чадвартай байвал энэ нь ийм төрлийн хүмүүс Намайг үнэхээр хайрладаг гэдгийг харуулах юм. Өөрөөр хэлбэл, хэрэв хүмүүстэй талх хуваж идэхгүй бол тэдний зовлон шаналлыг ойлгохгүй. Энэ хэлцийг хэрхэн тайлбарлах вэ? Эцэст нь Би гэсгээлтийн үеэр бүх хүнд өөрсдийг нь мэдүүлэх ба тэр үед тэднийг дуулуулж, инээлгэх болно. Намайг сэтгэл хангалуун байлгах итгэл та нарт үнэхээр байх уу? Тэгвэл та нар юуг хэрэгжүүлэх ёстой вэ? Одооноос эхлээд чуулган бүрийн хэрэг явдлыг тухайн чуулганы тохирох хүнд хариуцуулах ба элчүүд зүгээр л чуулганы амьдралаар амьдрах болно. Үүнийг “амьдралыг туулж үзэх” гэдэг юм. Та нар ойлгосон уу?

Гэсгээлт албан ёсоор хүн төрөлхтөн дээр бууж ирэхээс өмнө, Би эхлээд хүмүүс дээр “мэндлэх ажил” хийх болохоор эцэстээ тэд бүгд Намайг хангалуун болгох болно. Орхин явах хүмүүс ч гэсэн явахаасаа өмнө зовж, гэрчлэлээ дуусгах ёстой. Эс бөгөөс Би тэднийг зүгээр явуулчихгүй. Энэ нь хүмүүсийн зөрчлийг тэвчдэггүй Миний зан чанар болон Өөрийн хэлснээ биелүүлдэг Миний зан чанарын илрэл юм. Тэгсэнээр “Би хэлэх зүйлээ үнэн сэтгэлээсээ хэлдэг ба Миний хэлсэн зүйл хэрэгжиж, Миний хийсэн болгон мөнхрөх болно” гэсэн Амлалтаа гүйцээсэн байх

болно. Миний амнаас үг гармагц Миний Сүнс ч ажлаа эхэлдэг. Гартаа барьж байгаа “тоглоомоороо” хэн дураараа тоглож зүрхлэх вэ? Хүмүүс Миний гэсгээлтийг хүндэтгэлтэйгээр, дуулгавартайгаар хүлээн зөвшөөрөх ёстой. Хэн үүнээс зугтаж чадах юм бэ? Минийхээс өөр зам байж болох уу? Би чамд өнөөдөр газар дээр байх боломжийг олгосон бөгөөд чи үүнд баярлан хөөрч байгаа; харин маргааш Би чамд тэнгэрт очих боломжийг олгоход чи магтан дуулах болно. Тэрний дараагийн өдөр Би чамайг газар доор оруулах ба тэнд чи гэсгээлт хүртэнэ. Энэ бүгд Миний ажлын шаардлагууд биш гэж үү? Миний шаардлагуудын төлөө зовлон эдэлж, адислал хүртэхгүй хэн байх билээ? Та нар үүнээс ангид байж чадах уу? Газар дээрх Миний хүмүүсийн хувьд Миний шаардлагуудын төлөө, Миний хүслийн төлөө та нар юу хийх хэрэгтэй вэ? Та нар Миний ариун нэрийг амаараа магтдаг боловч зүрх сэтгэлдээ Намайг жигшдэг байж таарах уу? Миний төлөө ажил хийж, Миний зүрх сэтгэлийг хангалуун болгож, түүнчлэн өөрсдийгөө ойлгож, агуу улаан лууг эсэргүүцэх нь амархан даалгавар биш бөгөөд та нар үүнийхээ төлөөсийг төлөх ёстой. Намайг “төлөөс” гэж хэлэхээр юу гэж ойлгож байна вэ? Би үүнийг одоо хэлэлцэхгүй бөгөөд хүмүүст шууд хариулт өгөхгүй. Харин үүнийг өөрсдөө бодож үзээд дараа нь Миний асуултанд өөрсдийн үйлдэл, зан байдлаараа хариулах боломжийг Би тэдэнд олгоно. Тэгж чадах уу?

1992 оны 4 дүгээр сарын 27

38-Р БҮЛЭГ

Хүний туулсан зүйлд Миний ямар нэг ул мөр хэзээ ч байгаагүй, Миний үгийн удирдамж хэзээ ч байгаагүй. Үүний үр дүнд Би хүнийг үргэлж хол байлгасан ба дараа нь түүнийг орхиж явсан. Би хүн төрөлхтний дуулгаваргүй байдлыг жигшдэг. Яагаад гэдгийг нь мэдэхгүй; Би анхнаасаа хүнийг үзэн ядсан мэт санагддаг боловч тэднийг ихэд өрөвддөг. Тиймээс хүмүүс Надад үргэлж хоёр янзаар хандаж ирсэн—учир нь Би хүнийг хайрладаг, бас үзэн яддаг. Хүмүүсийн дундаас хэн Миний хайрыг үнэхээр хайхардаг вэ? Хэн Миний үзэн ядалтыг үнэхээр хайхардаг вэ? Миний нүдэнд хүн бол бүх зүйлийн дундах нэг шавар баримал мэт амьгүй, үхмэл зүйл. Хүн дуулгаваргүй байдлаасаа болж Миний уурыг байн байн хүргэдэг. Хүмүүсийн дунд амьдарч байхад, тэд Намайг үргэлж зориуд “эрж хайдаг” учраас гэнэт ирэх үед минь үл ялиг инээмсэглэн, Би газар дээр хүмүүстэй тоглож байгаа мэт байдаг. Тэд хэзээ ч Намайг нухацтай авч үздэггүй ба Надад хандах хандлагаас нь болоод Би хүн төрөлхтний “ажлын хэсгээс” “тэтгэвэрт гарахаас” өөр аргагүй болдог. Гэхдээ, Би “тэтгэвэрт гарсан” хэдий ч Миний “тэтгэврээс” ганц ч зоос дутаж болохгүй гэдгийг Би хэлмээр байна. Хүн төрөлхтний “ажлын хэсэгт” “ажилласан жил”-ээсээ үүдэн Би тэднээс Надад өгөх ёстой төлбөрийг шаардсаар байдаг. Хэдийгээр тэд

намайг орхисон ч Миний гараас зугтаж яаж чадах юм бэ? Би нэгэнтээ хүмүүсийг барих барьцаа тодорхой хэмжээнд сулруулж, махан биеийнхээ хүсэлд дурааpаа ташуурах боломж олгосон—үүнээс болоод тэд эрээ цээргүй цадиггүй авирлаж зүрхэлсэн ба бүгд махан биед амьдарч байгаа учраас Намайг үнэхээр хайрладаггүй гэдгийг үүнээс харж болно. Жинхэнэ хайрыг махан биеийн хариуд өгдөг юм гэж үү? Хүнээс Миний шаарддаг бүхэн махан биеийн “хайр” төдий юм гэж үү? Хэрвээ үнэхээр тийм байсан бол хүнд ямар үнэ цэн байх юм бэ? Хүмүүс бүгд хэрэггүй новш! Надад тэвчээрийн “онцгой хүч” байгаагүй сэн бол Би хүнийг аль хэдийн орхих байсан юм—“дээрэлхүүлэхийн” тулд тэдэнтэй хамт үлдэж яах сан билээ? Гэсэн ч Би тэвчдэг. Би хүний “бизнес”-ийн учрыг олохыг хүсдэг. Газар дээрх Миний ажил дуусмагц Би бүх зүйлийн “эзэн”-ийг шүүхийн тулд тэнгэр өөд өндөрт гарна; энэ бол Миний үндсэн ажил, учир нь хүнийг жигших жигшил минь аль хэдийн тодорхой хэмжээнд хүрсэн. Дайснаа үзэн яддаггүй хэн байх билээ? Дайснаа устгахгүй хэн байх билээ? Тэнгэрт Сатан Миний дайсан; газар дээр хүн Миний өстөн. Тэнгэр, газрын хоорондох нэгдлээс үүдэн Би тэднийг ес дэх үеэ хүртэл бүгд буруутай гэж үздэг бөгөөд ганц нь ч өршөөгдөхгүй. Намайг эсэргүүц гэж хэн тэдэнд хэлсэн юм бэ? Надад дуулгаваргүй бай гэж хэн тэдэнд хэлсэн юм бэ? Хүмүүс яагаад хуучин уг чанарынхаа ужиг хүлээсийг тастах чадваргүй байдаг юм бэ? Яагаад тэдний махан бие дотроо үргэлж томорч байдаг юм бэ? Энэ бүхэн нь хүнийг шүүх шүүлтийн минь нотолгоо юм. Бодит баримтад бууж өгөхгүй байж хэн зүрхлэх билээ? Миний шүүлт сэтгэл хөдлөлд автдаг гэж хэн хэлж зүрхлэх билээ? Би хүнээс өөр тул түүнийг орхидог, учир нь Би бол зүгээр л хүн төрөлхтний нэг биш.

Миний хийдэг бүхэнд үндэслэл, суурь байдаг; хүн Надад “үнэн баримтуудыг” өөрийн амаар “илчлэх” үед хүн төрөлхтний гэмт хэрэг Миний гэсгээлтийг хүртэхэд хангалттай болохоор Би тэднийг “цаазын тавцан” руу дагалдан явдаг. Иймээс Би хүмүүст сохроор гэсгээлт оноодоггүй, харин гэмт хэргийнх нь жинхэнэ нөхцөл байдалд нийцүүлэн хүмүүсийг гэсгээдэг. Тэгэхгүй бол тэрслүү байдлынхаа улмаас хүмүүс хэзээ ч Надад бөхийн ёсолж, буруугаа хүлээхгүй байх байсан. Өнөөгийн нөхцөл байдлаас болоод хүмүүс бүгд дурамжхан толгой бөхийдөг боловч зүрх сэтгэлдээ үнэмшээгүй хэвээр үлддэг. Би хүмүүст уулгахаар “барийн хоол” өгсөн тул тэдний дотор эрхтэн “дурангийн” өмнө тодорхой харагддаг. Хүмүүсийн гэдсэн доторх бузар заваан юм арилаагүй; тэдний венийн судсаар элдэв янзын бохир зүйл урсдаг тул тэдний бие доторх хор улам ихэсдэг. Хүмүүс ийм нөхцөл байдалд маш олон жил амьдарсан учраас тэд үүнд дасаж, үүнийг хачин гэж үзэхээ больсон. Үүний үр дүнд тэдний бие доторх нян боловсорч гүйцэн, уг чанар нь болдог ба хүн бүр тэдгээрийн эрхшээл дор амьдардаг. Ийм учраас хүмүүс зэрлэг адуу мэт хаа сайгүй гүйлддэг. Гэсэн ч тэд үүнийг хэзээ ч бүрэн хүлээн зөвшөөрдөггүй; зүгээр л үг дуугүй хүлээн зөвшөөрснөө илэрхийлэхийн тулд толгой дохидог. Үнэндээ хүн Миний үгийг үнэн сэтгэлээсээ авч үздэггүй. Хэрвээ тэд Миний үгийг сайн эм гэж үзсэн бол “эмчийн зааврыг дагаж”, доторх өвчнөө энэ эмээр эдгээх байсан юм.

Гэхдээ Миний оюун ухаанд, тэдний авирладаг байдал энэ хүслийг биеүүлж чадахгүй тул Би зөвхөн “шантрахгүй байж”, сонссон ч бай, үгүй ч бай тэдэнтэй үргэлжлүүлэн ярьж л чадна: Би үүргээ л биелүүлж байгаа. Хүн Миний ерөөлийг эдлэхийг хүсдэггүй, харин тамын тарчлааныг туулахыг илүүд үздэг—иймээс Би тэдний хүсэлтийг зөвшөөрч л чадна. Гэвч, Өөрийн нэр болон Өөрийн Сүнсийг тамд шившиглэхгүйн тулд Би эхлээд тэднийг сахилгажуулж, дараа нь тэдний хүсэлтийг “дуулгавартай дагаж”, тэднийг “баяр хөөрөөр дүүргэнэ.” Миний далбаан дор явангаа хаана ч, хэдийд ч Намайг шившиглэхийг Би хүнд зөвшөөрөхийг хүсдэггүй, ийм учраас Би түүнийг ахин дахин сахилгажуулдаг. Миний хатуу чанд айлдварын хязгаарлалт байгаагүй бол хүн өнөөдрийг хүртэл Миний өмнө зогссоор байж яаж чадах юм бэ? Хүмүүс Намайг явна гэж айсандаа л нүглээс татгалздаг бус уу? Тэд гэсгээлтээс айсандаа л гомдоллодоггүй гэдэг нь үнэн бус уу? Гагцхүү Миний төлөвлөгөөний төлөө шийдвэр гаргадаг хүн байна уу? Хүмүүс бүгд Намайг “оюуны чадавх” дутмаг бурханлаг чанартай гэж боддог боловч хүн чанараараа бүх зүйлийг нэвт шувт харж чадна гэдгийг минь хэн ухаарч чадах билээ? Хүмүүсийн хэлдгээр “Хадаас хадахад яах гэж лантуу ашиглана гэж?” Хүмүүс төрөлхөөсөө Намайг хайрладаг юм биш, харин гэсгээлтээс айсандаа Намайг “хайрладаг”. Хүмүүсийн дундаас хэн Намайг хайрладаг төрсөн бэ? Намайг өөрсдийнхөө зүрх сэтгэл шиг үздэг хэн байна вэ? Иймээс Би үүнийг хүний ертөнцийн онч үгээр нэгтгэн дүгнэж хэлье: Хүмүүсийн дунд Намайг хайрладаг хэн ч үгүй.

Хүмүүс Надаар хол шидэгдэж, зах хязгааргүй далайд унах вий гэсэндээ Би газар дээрх Өөрийн ажлыг төгсгөлд нь аваачихыг хүсдэг учраас л ажлынхаа хурдыг ийнхүү түргэсгэсэн. Би тэдэнд аливаа хэрэг явдлын үнэн мөнийг урьдчилан хэлсэн болохоор л тэд бага зэрэг сэрэмжтэй байдаг. Хэрвээ ингээгүй бол тэнгэр муухайрах гэж байхад хэн дарвуулаа өргөх юм бэ? Хүн бүр сэрэмжлэн ажиллаж байгаа. Тэдний зүрх сэтгэлд Би дээрэмчин болсон мэт байдаг. Би гэрээс нь бүх зүйлийг хураан авна гэдгээс тэд айдаг тул бүх хүч чадлаа дайчлан “хаалгаа” түлхэж, Намайг гэнэт эвдээд ороод ирэх вий гэдгээс үхтлээ айдаг. Хулчгар хархнууд шиг авирлахыг нь харах үедээ Би чимээгүйхэн орхин явдаг. Хүмүүсийн төсөөллөөр ертөнц сөнөх гэж байгаа мэт санагддаг тул бүгд сандран зугтаж, ухаан алдталаа айдаг. Тэр үед л Би хий үзэгдлүүд газар дээр хаа сайгүй хэрэн тэнүүчилж байгааг хардаг. Би өөрийн эрхгүй инээдэг бөгөөд Миний инээх дуунд хүн мэл гайхаж, балмагддаг. Тэр үед л Би хэрэг явдлын үнэн мөнийг ухаардаг тул Өөрийн инээмсэглэлээ барьж, газар дээр тохиолдож буй зүйлийг харахаа болиод, үүний оронд Өөрийн анхдагч төлөвлөгөөний дагуу ажилдаа буцан ордог. Хүмүүс хог хаягдлаас цаашгүй учраас Би хүмүүсийг Миний судалгааны загвар болон үйлчлэх үлгэр дуурайл хэмээн үзэхээ больсон. Намайг хаямагц тэд ямар ч хэрэггүй болно—тэд бол хэсэг хаягдал. Энэ удаа Би тэднийг үндсээр нь устгаж, гал руу шиднэ. Хүмүүсийн оюун ухаанаар бол, Миний шүүлт, сүр жавхлан, уур хилэн дотор Миний өршөөл, хайр энэрэл агуулагддаг. Гэхдээ Би тэдний сул талуудыг хэдийнээ үл

тоомсорлож, Өөрийн өршөөл, хайр энэрлийг аль хэдийн буцаан авсан гэдгийг тэд мэддэггүй, тийм ч учраас тэд одоогийн энэ байдалдаа байгаа юм. Нэг ч хүн Намайг мэдэж чадахгүй, мөн Миний үгийг ойлгож, Миний царайг харж, эсвэл Миний хүслийг ухан ойлгож ч чаддаггүй. Энэ нь хүний одоогийн байгаа байдал биш гэж үү? Тэгвэл Намайг өршөөл, хайр энэрэлтэй гэж хэлж яаж болох юм бэ? Би хүний сул талуудыг тоодоггүй ба хангалтгүй байдлыг нь “анхааралдаа авдаггүй.” Энэ нь мөн л Миний өршөөл, хайр энэрэл юм гэж үү? Эсвэл хүмүүсийг гэх Миний хайр юм гэж үү? Хүмүүс бүгд Намайг “хий дэмий эелдэг үг” хэлдэг гэж боддог тул Миний хэлсэн үгэнд итгэдэггүй. Гэхдээ, “Энэ нь өөр эрин тул Миний өршөөл, хайр энэрэл одоо байдаггүй; гэвч Би бол үүрд хэлснээ хийдэг Бурхан” гэдгийг мэддэг хүн байна уу? Хүн төрөлхтний дунд байхад минь хүмүүс оюун ухаандаа Намайг Хамгийн Дээд гэж үздэг тул Намайг мэргэн ухаанаараа ярих дуртай гэж боддог. Үүнээс болоод тэд Миний үгэнд үргэлж хагас хугас итгэдэг. Гэхдээ Миний үгийн ар дахь дүрэм журмыг ухаарч чадах хүн байна уу? Эсвэл Миний үгийн эх сурвалжийг ухаарч чадах хүн байна уу? Үнэндээ юу биелүүлэхийг хүсэж байгааг минь ухан ойлгож чадах хүн байна уу? Эсвэл Миний удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийн нарийн учрыг нэвт харж чадах хүн байна уу? Хэн Миний итгэмжит хүн болж чадах вэ? Бүх зүйлийн дотроос Надаас өөр хэн яг юу хийж байгааг минь мэдэж чадах вэ? Мөн хэн Миний эцсийн зорилгыг мэдэж чадах вэ?

1992 оны 4 дүгээр сарын 30

39-Р БҮЛЭГ

Би өдөр бүр орчлон ертөнцийн дээгүүр явж, Өөрийн гараар бүтээсэн бүх зүйлийг ажигладаг. Тэнгэрийн дээр Миний амрах газар байдаг ба тэнгэрийн дор Миний алхах газар байдаг. Би бүх зүйлийн дунд буй бүхнийг захирч, бүх зүйлийн дундах бүх юмыг удирдаж, бүх зүйлийг байгалийн жамаар нь явуулж, байгалийн хуулинд захирагдуулдаг. Би дуулгаваргүй хүмүүсийг үзэн ядаж, Намайг эсэргүүцдэг агаад өөрсдийн ангилалд ордоггүй хүмүүсийг зэвүүцдэг учраас бүх зүйлийг ямар ч эсэргүүцэлгүйгээр Өөрийн зохицуулалтад захирагдуулж, орчлон ертөнцийн дээрх болон доторх бүх зүйлийг эмх журамтай болгоно. Хэн Намайг дур зоргоороо эсэргүүцсээр байж зүрхлэх вэ? Хэн Миний гарын зохицуулалтыг дуулгавартай дагахгүй байж зүрхлэх вэ? Хүн яаж Миний эсрэг тэрслэх “сонирхолтой” байж чадах юм бэ? Би хүмүүсийг өөрсдийнх нь “өвөг дээдсийн” өмнө аваачиж, өвөг дээдсээр нь тэднийг гэр бүл рүү нь буцаан хүргүүлнэ, мөн өвөг дээдсийнхээ эсрэг тэрсэлж, Миний талд буцаж ирэхийг тэдэнд зөвшөөрөхгүй. Энэ бол Миний төлөвлөгөө. Өнөөдөр Миний Сүнс газар дэлхий даяар явж, бүх төрлийн хүмүүсийг дугаарлаж, төрөл бүрийн хүнийг өөр өөр тэмдгээр тэмдэглэдэг, ингэснээр өвөг дээдэс нь

тэднийг гэр бүл рүүгээ амжилттайгаар буцаан аваачих бөгөөд Би тэдний талаар үргэлжлүүлэн “санаа зовох” хэрэггүй, энэ нь дэндүү төвөгтэй; тиймээс Би бас хөдөлмөрөө хувааж, хичээл чармайлтаа хуваарилдаг. Энэ бол Миний төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд нэг ч хүн үүнийг тасалдуулж чадахгүй. Би бүх зүйлийг удирдуулахын тулд тэнд байгаа бүхнээс тохиромжтой төлөөлөгчдийг сонгож, бүгдийг нь Өөрийнхөө өмнө эмх журамтай дуулгавартай байлгана. Би тэнгэрүүдийн дээгүүр ахин дахин хэрэн хэсэж, тэдгээрийн доогуур үргэлж алхдаг. Хүмүүсийн ирж буцдаг асар том дэлхий ертөнцийг харж, газар дээр шигүү бөөгнөрсөн хүн төрөлхтнийг ажиглаж, газар дэлхий дээр амьдардаг шувууд, араатнуудыг хараад өөрийн эрхгүй сэтгэл хөдөлдөг. Бүтээлийн цаг үед Би бүх зүйлийг бүтээсэн ба Миний зохицуулалтын дор бүхий л зүйл өөрсдийнхөө байранд үүргээ биелүүлдэг учраас Би өндрөөс инээдэг, тэнгэрийн доорх бүх зүйл Миний инээдийн чимээг сонсох үедээ даруй онгод ордог, учир нь энэ мөчид Миний агуу ажиллагаа дуусдаг. Би хүний дотор тэнгэрийн мэргэн ухааныг нэмж, бүх зүйлийн дунд түүгээр Өөрийгөө төлөөлүүлдэг, учир нь Би хүнийг Надад дуулгаваргүй бус байж, зүрх сэтгэлийнхээ гүнээс Намайг магтдаг төлөөлөгчөө болгохын тулд бүтээсэн билээ. Хэн эдгээр энгийн үгийг биелүүлж чадах вэ? Яагаад хүн зүрх сэтгэлээ үргэлж өөртөө байлгадаг юм бэ? Түүний зүрх сэтгэл Миний төлөө байдаг бус уу? Би хүнээс аливааг болзолгүйгээр шаарддаг юм биш, харин тэр үргэлж Надад харьяалагддаг байсан. Би Өөртөө харьяалагддаг зүйлсийг бусдад санаандгүй өгч яаж чадах юм бэ? Өөрийнхөө хийсэн “хувцсыг” өөр нэгэнд өмсүүлэхээр өгч яаж чадах юм бэ? Хүмүүсийн нүдээр бол Би ухаан мэдрэлээ алдаж, сэтгэцийн өвчнөөс болж шаналан, хүний арга замын юуг ч ойлгодоггүй юм шиг байдаг; Би тэнэг хүн шиг байдаг. Иймээс хүмүүс үргэлж Намайг гэнэн хүн гэж үздэг боловч Намайг хэзээ ч үнэхээр хайрлаагүй. Хүний хийдэг бүхэн санаатайгаар Намайг хуурахын төлөө байдаг учраас уурлан хилэгнэсэндээ Би бүх хүн төрөлхтнийг үндсээр нь устгана. Миний бүтээсэн бүх зүйлийн дундаас хүн төрөлхтөн л Намайг мэхлэх арга бодож олохоор үргэлж оролддог бөгөөд үүнээс л болоод Би хүн бол бүх зүйлийн “захирагч” гэж хэлдэг.

Өнөөдөр Би бүх хүнийг цэвэршүүлэхийн тулд “асар том зуух” руу шиддэг. Би өндөрт зогсоод хүмүүс галд шатаж, галын дөлөнд хуйхлуулж байгааг анхааралтай харж байдаг ба хүмүүс галын шахалтад автаад баримтуудыг өчдөг. Энэ нь Миний ажилладаг арга барилуудын нэг юм. Хэрвээ ийм байгаагүй бол хүмүүс “даруухан” дүр эсгэж, өөрсдийнхөө туршлагын талаар ярихын тулд хэн ч эхэлж ам нээхийг хүсэхгүй, харин бүгд бие бие рүүгээ харах байсан юм. Энэ нь яг нарийндаа Миний мэргэн ухааны биелэлт юм, учир нь Би өнөөдрийн хэрэг явдлуудыг эрин үеүдээс өмнө урьдчилан тогтоосон билээ. Тиймээс хүмүүс олсоор хөтлүүлж яваа юм шиг, мөн мэдрэлгүй болсон юм шиг өөрийн мэдэлгүй зууханд ордог. Галын дайралтаас хэн ч зугтаж чадахгүй, тэд бие бие рүүгээ “дайрч”, “баяр хөөртэйгээр яаравчлан”, зуухан дахь хувь заяаныхаа талаар түгшсээр шатаж үхэх болно гэдгээс ихэд айдаг. Намайг галыг өрдөх үед энэ нь даруй дүрэлзэж, тэнгэр лүү асдаг бөгөөд галын дөл

Миний өмсгөлийг ахин дахин шүргэж, тэдгээрийг зуух руу татан оруулахаар оролдох мэт байдаг. Хүмүүс Намайг нүдээ бүлтийлгэн хардаг. Тэр даруй Би галыг даган зуух руу ордог ба энэ мөчид галын дөл ихсэж, хүмүүс хашхирдаг. Би галын дөл дунд хэрэн явдаг. Галын дөл их боловч Намайг гэмтээх гэдэггүй бөгөөд Би Өөрийн биед нөмөрсөн өмсгөлөө дахин нэгэнтээ галын дөлд өгөвч тэд Надаас зайгаа барьдаг. Тэр үед л хүмүүс галын дөлний гэрэлд Миний жинхэнэ нүүр царайг тодорхой хардаг. Тэд зуухны төөнөсөн халуунд байгаа учраас Миний нүүр царайг хараад тал тал тийшээ зугтдаг бөгөөд зуух тэр дороо “буцалж” эхэлдэг. Галын дөл доторх бүх хүн дүрэлзсэн галд цэвэршүүлэгдсэн хүний Хүүг хардаг. Түүний биедээ өмссөн хувцас жирийн хэдий ч тэр нь хамгийн гоёмсог; Түүний хөл дэх гутал хэдийгээр онцын содон биш боловч асар их атаархал төрүүлдэг; Түүний царайнаас цогтой гэрэл цацарч, нүд нь гялалздаг бөгөөд хүмүүс нүднийх нь гэрэлд л Түүний жинхэнэ нүүр царайг тодорхой харж байх шиг байдаг. Хүмүүс мэл гайхаж, Түүний биедээ өмссөн цагаан дээл хувцсыг болон мөрийг нь даган доош унжсан ноос шиг цагаан үсийг нь хардаг. Ялангуяа цээжиндээ бүсэлсэн алт нь нүд гялбам гэрэл цацруулж байхад хөл дэх гутал нь бүр ч илүү сэтгэл хөдөлгөм байдаг. Хүний Хүүгийн өмссөн гутал гал дунд үлдсэн учраас хүмүүс гайхалтай юм гэж итгэдэг. Гэнэтийн хүчтэй өвдөлтийн үеэр л хүмүүс хүний Хүүгийн ам руу хардаг. Хэдий тэд галын цэвэршүүлэлт дунд байгаа ч хүний Хүүгийн амнаас гарсан ямар ч үгийг ойлгодоггүй, тиймээс энэ мөчид тэд хүний Хүүгийн таатай дуу хоолойноос өөр юу ч сонсдоггүй боловч Түүний аман доторх хурц сэлмийг хардаг, Тэр өөр юу ч айлдаагүй байсан ч гэсэн Түүний сэлэм хүнийг шархлуулдаг. Галын дөлд бүслэгдсэн хүмүүс өвдөлтийг тэвчинэ. Сониуч зандаа хөтлөгдөн тэд хүний Хүүгийн ер бусын дүр төрхийг харсаар байдаг бөгөөд энэ мөчид л тэд Түүний гар дахь долоон од алга болсныг олж мэддэг. Хүний Хүү газар дээр биш, зууханд байгаа болохоор Түүний гар дахь долоон од алга болсон, учир нь тэдгээр нь ердөө зүйрлэл юм. Энэ мөчид тэдгээр нь дурдагдахаа больдог ч хүний Хүүгийн янз бүрийн хэсгүүдэд хуваарилагддаг. Долоон одны оршин тогтнол нь хүмүүсийн ой санамжид тавгүй байдлыг авчирдаг. Өнөөдөр Би хүнд бэрхшээл учруулахаа больж, хүний Хүүгээс долоон одыг аваад, хүний Хүүгийн бүх хэсгүүдийг нэгэн бүхэл болгон нийлүүлнэ. Зөвхөн энэ мөчид л хүн Миний дүр төрхийг бүхэлд нь харна. Хүмүүс Миний Сүнсийг Миний махбодоос салгахаа болино, учир нь Би газраас өндөрт гарсан билээ. Хүмүүс Миний жинхэнэ нүүр царайг харсан ба цаашид Намайг салгахгүй, мөн Би цаашид хүний гүжирдлэгийг амсахгүй. Би асар том зуух руу хүнтэй хамт алхан орсон учраас тэр Надад найдсаар байдаг ба Миний оршин тогтнолыг ухамсараараа мэдэрдэг. Тиймээс шатаж буй галын дундах бүх шижир алт аажмаар Надад цуглардаг, энэ нь дор бүрнээ төрлийнхөө дагуу ангилагдах яг тэр мөч юм. Би “металл” болгоныг ангилж, бүгдийг нь гэр бүл рүү нь буцаадаг бөгөөд тэгэхэд л бүх зүйл шинэчлэгдэж эхэлдэг…

Хүн маш их хольцтой учраас Би түүнийг шатаахын тулд зуух руу чулууддаг. Гэсэн ч галын дөл түүнийг үндсээр нь устгадаггүй, харин цэвэршүүлдэг болохоор

Би түүнээс таашаал авах боломжтой—учир нь Миний хүсдэг зүйл бол бохир, бузартсан зүйл биш, харин ямар ч хольцгүй шижир алтаар хийгдсэн зүйл билээ. Хүмүүс Миний сэтгэл санааг ойлгодоггүй тул “мэс заслын ширээн” дээр гарахаасаа өмнө түгшүүрт автан, тэднийг задлан шинжилснийхээ дараа Би мэс заслын ширээн дээр хэвтэж байхад нь хөнөөх гэж байгаа мэт байдаг. Би хүмүүсийн сэтгэл санааны байдлыг ойлгодог болохоор Би хүн төрөлхтний гишүүн мэт байдаг. Хүний “золгүй явдлыг” Би асар их өрөвддөг бөгөөд хүн яагаад “өвдсөнийг” мэддэггүй. Хэрвээ хүн эрүүл, хөгжлийн бэрхшээлгүй байсан бол төлбөр төлж, мэс заслын ширээн дээр цагийг өнгөрөөх хэрэг юу сан билээ? Гэхдээ баримтуудаас булзаж болохгүй—“хүнсний эрүүл ахуйд” анхаарал хандуулахгүй бай гэж хэн хүнд хэлсэн юм бэ? Эрүүл байхад бүү анхаарал хандуул гэж хэн түүнд хэлсэн юм бэ? Өнөөдөр Надад өөр ямар арга байгаа юм бэ? Хүнийг гэх энэрлээ харуулахын тулд Би түүнтэй хамт “мэс заслын өрөөнд” ордог—хүнийг хайрла гэж хэн Надад хэлсэн юм бэ? Тиймээс Би Өөрөө “мэс засалчийн хутгыг” барьж аваад, аливаа урхагаас сэргийлэхийн тулд хүнд “мэс засал хийж” эхэлдэг. Хүнд гаргах Миний үнэнч занг хараад хүмүүс Надад талархсанаа илэрхийлж өвдөлт шаналлын дунд нулимс унагадаг. Хүмүүс Намайг зөв шударга байдлыг үнэлдэг Нэгэн тул зовлонд унасан “найз” нартаа гараа сунган тусална гэдэгт итгэдэг, мөн хүмүүс Миний сайхан сэтгэлд бүр ч их талархаж, өвчин нь эдгэх үед Надад “бэлэг” илгээнэ гэж хэлдэг—гэхдээ Би тэрхүү илэрхийлж буй санаа зорилгыг нь тоодоггүй, харин хүнд мэс засал хийхдээ л анхаардаг. Бие махбодынхоо сул талаас болж хутганы нөлөөн дор хүн нүдээ тас аниад, мэс заслын ширээн дээр цочирдон хэвтдэг—гэсэн ч Би анзаардаггүй, зүгээр л хийж буй ажлаа үргэлжлүүлдэг. Мэс засал дуусах үед хүмүүс “барын амнаас” мултарсан байдаг. Би тэднийг баялаг шим тэжээлээр тэжээдэг бөгөөд тэд үүнийг мэддэггүй хэдий ч доторх шим тэжээл нь аажмаар ихэсдэг. Дараа нь Би тэдэн рүү инээмсэглэх бөгөөд эрүүл мэнд нь сэргэсний дараа л тэд Миний жинхэнэ нүүр царайг тодорхой хардаг тул Намайг илүү их хайрлаж, эцэг шигээ үздэг—энэ нь тэнгэр, газрын хоорондох холбоо биш гэж үү?

1992 оны 5 дугаар сарын 4

40-Р БҮЛЭГ

Би тэнгэрүүдийг нураах гэж байгаа юм шиг хүмүүс Миний хөдөлгөөн бүрийг анхааралтай ширтдэг бөгөөд Миний үйл хэрэг туйлын ойлгогдошгүй байдаг мэт Миний хийж байгаа зүйлээс болж үргэлж гайхширдаг. Тиймээс тэд хийдэг бүхэндээ Надаас дохио авч, Тэнгэрийг гомдоон, “мөнх бусын ертөнц” рүү шидэгдэх вий гэхээс ихэд айдаг. Би хүмүүсийн эсрэг ашиглах юм олохоор хичээдэггүй, эсвэл тэдний дутагдлыг Өөрийн ажлын бай болгодоггүй. Энэ мөчид тэд тун аз жаргалтай

байж, Надад найдаж эхэлдэг. Намайг хүнд юм өгөх үед хүмүүс Намайг амь шигээ хайрладаг боловч тэднээс юм гуйх үед тэд Надаас зайлсхийдэг. Яагаад энэ вэ? Тэд хүний ертөнцийн “шударга ёс, үндэслэлтэй байдлыг” хэрэгжүүлж чадахгүй гэж үү? Яагаад Би хүмүүст ахин дахин ийм шаардлага тавьдаг вэ? Надад үнэхээр юу ч байдаггүй гэж үү? Хүмүүс Надад гуйлгачин шиг ханддаг. Намайг тэднээс юм гуйх үед тэд өөрсдийн “үлдэгдлийг” Миний өмнө авчирч, Надаар “таашаан эдлүүлээд”, Намайг онцгойлон халамжилж байна гэж ч хэлдэг. Би хүний муухай царай болон хачин байдлыг хардаг бөгөөд дахин нэгэнтээ хүнийг орхин явдаг. Ийм нөхцөл байдалд хүмүүс ойлгохгүй хэвээр үлддэг бөгөөд Миний татгалзсан зүйлсийг дахин нэгэнтээ буцаан авч, эргэн ирэхийг минь хүлээж байдаг. Би хүний төлөө маш их цаг зарцуулж, асар их төлөөс төлсөн—гэхдээ энэ удаа үл мэдэгдэх учир шалтгааны улмаас хүмүүсийн мөс чанар анхдагч чиг үүргээ биелүүлж огт чадахгүй хэвээр үлддэг. Үүний үрээр ирээдүй үеийнхэнд зориулсан “лавлах” болгохын тулд Би тэдний энэ “байнгын эргэлзээг” “нууц үгсийн” дунд жагсаадаг, учир нь энэ бол хүмүүсийн “шаргуу хөдөлмөрөөс” төрөн гарсан “шинжлэх ухааны судалгааны үр дүн” юм; Би яаж тэдгээрийг санаандгүй арилгаж болох билээ? Энэ нь хүмүүсийн сайн санааг “хөсөрдүүлж” байгаа хэрэг болох бус уу? Эцсийн эцэст Би мөс чанартай бөгөөд хүнтэй хамт зальхай, хуйвалдсан үйл хийдэггүй—Миний үйл хэрэг тийм байдаг бус уу? Энэ нь хүний ярьдаг “шударга ёс, үндэслэлтэй байдал” биш гэж үү? Хүмүүсийн дунд Би өнөөг хүртэл тасралтгүй ажилласан. Өнөөдрийнх шиг цаг ирэхэд хүмүүс мөн л Намайг мэдэлгүй, Надад танихгүй хүн мэт хандсаар байдаг бөгөөд Би тэднийг “мухардалд” оруулсан учраас Намайг бүр ч их үзэн яддаг. Энэ удаа тэдний зүрх сэтгэл дэх хайр аль хэдийн ул мөргүй алга болсон. Би бардамнаж байгаа юм биш, хүнийг дорд үзэж байгаа хэрэг бүр ч биш. Би хүнийг үүрд мөнхөд хайрлаж чадна, бас үүрд мөнх үзэн ядаж чадна, энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй, учир нь Надад цөхрөлтгүй зан бий. Гэсэн ч хүнд ийм цөхрөлтгүй зан байдаггүй, тэр Надад үргэлж туйлбаргүй ханддаг ба Намайг ам нээх үед бага зэргийн анхаарал хандуулаад, Намайг амаа хамхин юу ч хэлэхгүй байх үед асар том ертөнцийн давлагаан дунд алга болдог. Тиймээс Би үүнийг өөр нэг онч мэргэн үгээр товч илэрхийлдэг: Хүмүүст цөхрөлтгүй зан дутагддаг тул Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгах чадваргүй.

Хүмүүсийг зүүд нойронд умбаж байх зуур Би Өөрийн гар дахь “үхлийн үнэрийг” хүмүүсийн дунд цацан, дэлхий ертөнцийн улс орнуудаар аялдаг. Бүх хүн эрч хүчтэй байдлаа даруй орхиж, хүний амьдралын дараагийн үед ордог. Хүн төрөлхтний дунд ямар ч амьд амьтан харагдахаа больж, цогцсууд хаа сайгүй тарж, эрч хүчээр бялхсан зүйлс нэн даруй ул мөргүй алга болж, цогцсуудын амьсгаа боогдуулам үнэр газар нутаг даяар шингэдэг. Би Өөрийнхөө нүүрийг даруй бүтээж, хүнээс холдон явдаг, учир нь Би ажлын дараагийн алхмыг эхлүүлж, амь орсон хүмүүст амьдрах газар өгч, бүх хүнийг хүслэнт газар нутагт амьдруулдаг. Энэ бол ерөөгдсөн газар нутаг—хүнд зориулж Миний бэлтгэсэн—уй гашуу, гаслангүй газар

нутаг билээ. Хөндийн горхиноос урсаж буй ус тув тунгалаг бөгөөд тасралтгүй урсаж, хэзээ ч ширгэдэггүй; хүмүүс Бурхантай эв зохицолтой амьдарч, шувууд жиргэж, сэвшээ салхи, илчит нарны дунд тэнгэр газар хоёулаа амарна. Өнөөдөр энд бүх хүний цогцос эмх замбараагүй хэвтэж байдаг. Хүмүүст мэдэгдэлгүйгээр Би Өөрийн гар дахь тахлыг сул тавьж, хүний биеийг илжрүүлээд толгойноос нь хөл хүртэл махан биеийн ямар ч ул мөр үлдээлгүй орхих бөгөөд хүнээс холдон явна. Би дахин хэзээ ч хүнтэй хамт цуглахгүй, дахин хэзээ ч хүмүүсийн дунд ирэхгүй, учир нь Миний бүхий л удирдлагын эцсийн үе шат төгсгөлдөө очсон бөгөөд Би хүн төрөлхтнийг дахин бүтээхгүй, хүнд дахин анхаарал тавихгүй. Миний амнаас гарсан үгийг уншсаныхаа дараа хүмүүс бүгд итгэл найдвараа алдана, учир нь тэд үхэхийг хүсдэггүй—гэхдээ “амь орохын” төлөө “үхдэггүй” хэн байх билээ? Тэднийг амьдруулах ид шид Надад байхгүй гэж хүмүүст хэлэх үед минь тэд шаналсандаа асгаруулан уйлна; үнэндээ Би Бүтээгч хэдий ч Надад хүмүүсийг үхүүлэх эрх мэдэл байдаг бөгөөд тэднийг амьдруулах чадвар байдаггүй. Үүндээ Би хүнээс уучлал гуйдаг. Тиймээс Би “түүнд төлж баршгүй өртэй” гэдгээ хүнд урьдчилан хэлсэн—гэсэн ч тэр Намайг найрсаг байна гэж бодсон. Өнөөдөр баримтууд гарч ирснээр Би мөн л ингэж хэлдэг. Ярих үедээ Би баримтуудаас зөрдөггүй. Өөрсдийн үзлээр хүмүүс, үгээ хэлдэг хэтэрхий олон арга зам Надад байдаг гэж боддог тул өөрсдөд нь өгсөн Миний үгээс үргэлж зуурангаа өөр зүйлд найдаж байдаг. Эдгээр нь хүний буруу сэдэл биш гэж үү? Эдгээр нөхцөл байдал дор хүн Намайг үнэхээр хайрладаггүй гэдгийг Би “зоригтойгоор” хэлж зүрхэлдэг. Би мөс чанараасаа нүүр буруулж, баримтуудыг мушгин гуйвуулахгүй, учир нь Би хүмүүсийг өөрсдийнх нь хүслэнт газар нутаг руу аваачихгүй; эцэст нь Миний ажил дуусах үед Би тэднийг үхлийн газар нутаг руу хөтөлнө. Иймээс хүмүүс Миний талаар гомдоллохгүй байсан нь дээр—энэ нь хүмүүс Намайг “хайрладгаас” болдоггүй гэж үү? Ерөөлийн төлөөх тэдний хүсэл хэтэрхий хүчтэйгээс болдоггүй гэж үү? Хэрвээ хүмүүс ерөөл эрж хайхыг хүсээгүй бол ийм “золгүй явдал” юу гэж байх юм бэ? Хүмүүсийн надад хандах “үнэнч зангийн” улмаас, тэд Намайг олон жилийн турш дагаж, ямар ч хувь нэмэр оруулаагүй мөртөө шаргуу ажилласан учраас Би тэдэнд “нууц танхимд” болж байгаа зүйлийн багахныг илчилдэг: Өнөөдөр Миний ажил тодорхой түвшинд хараахан хүрээгүй, хүмүүс галтай нүх рүү хараахан шидэгдээгүй байгаагаас үүдэн Би тэдэнд аль болох хурдан явахыг зөвлөнө—үлдсэн бүх хүн гарцаагүй сайнаасаа муу нь их байх болно. Би тэдний төлөө “эд баялагт хүрэх хаалгыг” дэлгэнэ; явахыг хүсэж байгаа хэн боловч аль болох хурдан замдаа гарах хэрэгтэй—хэрвээ тэд гэсгээлт ирэх хүртэл хүлээвэл хэтэрхий оройтсон байх болно. Эдгээр үг тохуурхал биш—жинхэнэ баримтууд юм. Миний үг хүнд сайн санааны үндсэн дээр хэлэгддэг бөгөөд хэрвээ та нар одоо явахгүй бол хэзээ явах юм бэ? Хүмүүс үнэхээр Миний үгэнд итгэж чадах уу?

Би хүний хувь заяаны талаар хэзээ ч тийм их бодож байгаагүй; Би хүмүүст хязгаарлагдахгүйгээр зүгээр л Өөрийнхөө хүслийг дагадаг. Тэдний айдсаас болоод

Би яаж гараа татан авч болох юм бэ? Өөрийнхөө бүхий л удирдлагын төлөвлөгөөнд Би хүний туршлагын төлөө ямар нэгэн нэмэлт зохицуулалт хийж байсан удаагүй. Би ердөө анхдагч төлөвлөгөөнийхөө дагуу л үйлддэг. Урьд нь хүмүүс өөрсдийгөө Миний төлөө “өргөн барьдаг” байсан бөгөөд Би тэдэнд халуун ч, эсвэл хүйтэн ч хандаагүй. Өнөөдөр тэд өөрсдийгөө Миний төлөө “золиосолсон” ба Би тэдэнд халуун ч биш, хүйтэн ч биш хандсаар байдаг. Хүмүүс Миний төлөө амиа золиосолдгоос болоод Би бардамнадаггүй, мөн Би тоймгүй их баяр хөөрт ч автдаггүй, харин Өөрийнхөө төлөвлөгөөний дагуу тэднийг цаазын тавцан руу үргэлжлүүлэн илгээдэг. Нүглээ улайх үеийн тэдний хандлагад Би анхаарал тавьдаггүй—Миний хүйтэн хөндий зүрх сэтгэлийг хүний зүрх сэтгэл яаж хөдөлгөж чадах юм бэ? Би хүн төрөлхтний дундах сэтгэлийн хөдөлгөөнтэй амьтдын нэг гэж үү? Би сэтгэл хөдлөлгүй гэдгээ хүмүүст олон удаа сануулсан боловч тэд үл ялиг инээмсэглээд, Намайг зүгээр л найрсаг байна гэж боддог. “Би хүний ертөнцийн амьдралын гүн ухааны талаар мэддэггүй” гэж Би хэлсэн боловч хүмүүс хэзээ ч тэгж бодоогүй ба Миний үгээ хэлдэг арга барил маш олон гэж хэлсэн. Хүний энэхүү үзлийн хязгаарлалтуудаас болоод Би хүмүүстэй ямар өнгөөр, ямар аргаар ярихаа мэддэггүй—иймээс өөр ямар ч сонголтгүйгээр Би гагцхүү шулуухан ярьдаг. Би өөр юу хийж чадах билээ? Хүмүүсийн ярьдаг арга барил маш олон—“Бид сэтгэл хөдлөлд найдалгүй, зөв шударга байдлыг хэрэгжүүлэх ёстой” гэж тэд хэлдэг, энэ нь олон жилийн турш хашхирсан нэг төрлийн уриа лоозон нь боловч тэд хэлснээ хийж чаддаггүй ба үг нь хий дэмий байдаг—иймээс хүмүүс “үг, үйлдлээ нийцүүлэх” чадваргүй гэж Би хэлдэг. Тийнхүү үйлдэх нь Намайг дуурайж байгаа хэрэг гэж хүмүүс зүрх сэтгэлдээ боддог—гэсэн ч Би тэдний дуурайж байгааг огт сонирхдоггүй, үүнээс үхтэлээ залхдаг. Яагаад хүмүүс үргэлж өөрсдийг нь тэжээдэг Нэгний эсрэг ханддаг юм бэ? Би хүнд хэтэрхий багыг өгсөн гэж үү? Яагаад хүмүүс Миний ар хударгаар Сатаныг үргэлж нууцаар шүтдэг юм бэ? Тэд Миний төлөө ажиллаж, Миний өгдөг сарын цалин амьжиргааных нь зардалд хүрэлцдэггүй болохоор цалингаа хоёр дахин ихэсгэхийн тулд ажлын бус цагаараа өөр ажил хайдаг мэт байдаг—хүмүүсийн зарлага хэтэрхий их учраас тэд хэрхэн амь зуухаа мэддэггүй юм шиг санагддаг. Хэрвээ үнэхээр тийм байсан бол Миний “үйлдвэрийг” орхин явахыг Би тэднээс шаардах байсан. Миний төлөө ажиллалаа гээд ер онцгойлон хандахгүй гэдгийг Би хүнд аль хэдийн тайлбарласан: Би хүмүүст бүгдэд нь ялгаагүй шударга, үндэслэлтэй ханддаг ба “шаргуу ажиллавал ихийг олно, бага ажиллавал багыг олно, ажиллахгүй бол юу ч олохгүй” хэмээх системийг нэвтрүүлсэн. Ярих үедээ Би юу ч нуудаггүй; хэрвээ Миний “үйлдвэрийн дүрэм журмыг” хэтэрхий хатуу чанд гэж бодож байгаа хүн байвал нэн даруй явах ёстой ба Би хотоос явах “аяллын зардлыг” нь төлнө. Тийм хүмүүстэй харилцахдаа Би “аядуу зөөлөн” байдаг бөгөөд тэднийг үлдээхээр хүчилдэггүй. Энэ тоо томшгүй олон хүний дундаас Миний зүрх сэтгэлийн дагуу байдаг “ажилчныг” Би олж чадахгүй гэж үү? Хүмүүс Намайг дутуу үнэлэх ёсгүй! Хэрвээ хүмүүс Надад

дуулгаваргүй хандсаар байж, өөр хаа нэгтээ “ажилд” орохыг хүсэж байгаа бол Би тэднийг хүчлэхгүй—Би үүнийг дэмжинэ, Надад ямар ч сонголт байхгүй! Надад хэтэрхий олон “дүрэм журам, зохицуулалт” байдгаас энэ нь болдог бус уу?

1992 оны 5 дугаар сарын 8

41-Р БҮЛЭГ

Би нэгэнтээ хүмүүсийн дунд агуу ажил хийсэн боловч тэд анзаараагүй, тиймээс Би үүнийг тэдэнд алхам алхмаар илчлэхийн тулд Өөрийн үгийг ашиглах хэрэгтэй болсон. Гэсэн ч хүн Миний үгийг ойлгоогүй бөгөөд Миний төлөвлөгөөний зорилгыг мэдэхгүй хэвээр үлдсэн юм. Тиймээс дутагдал, сул талуудынхаа улмаас хүмүүс Миний удирдлагад саад болох зүйлсийг хийж, энэ нь бүх төрлийн бузар сүнснүүдэд орох боломжийг олгосон. Тэгсэнээр, хүн төрөлхтөн тэрхүү бузар сүнснүүдийн хохирогч болж, бүхэлдээ бузартах хүртлээ тэдэнд тамлуулсан. Энэ үед л Би хүний санаа, зорилгыг тодорхой харсан юм. Би үүлэн дундаас ийнхүү шүүрс алдсан: Хүн яагаад үргэлж өөрийнхөө төлөө үйлддэг юм бэ? Миний гэсгээлт тэднийг төгс болгох учиртай биш гэж үү? Би тэдний эерэг хандлагыг албаар дараад байгаа гэж үү? Хүний хэл маш сайхан, зөөлөн мөртөө түүний үйлдэл тэр чигтээ эмх замбараагүй байдаг. Хүнд тавьсан Миний шаардлага яагаад үргэлж талаар болдог вэ? Би нохойноос модонд авирахыг шаардаж байгаа мэт хэцүү зүйл шаардаад байгаа юм болов уу? Би хий дэмий юмны төлөө сүржигнээд байгаа юм болов уу? Бүхий л удирдлагын төлөвлөгөөнийхөө туршид Би янз бүрийн “туршилтын талбай” гаргасан, гэсэн хэдий ч тухайн газар нутаг, үржил шимгүй, олон жил нар үзээгүйн улмаас, үргэлж өөрчлөгдөн, газар “нуран унахад” хүргэж байна. Тиймээс Би Өөрийн ой санамжаас ийм төрлийн тоо томшгүй олон газрыг арчиж хаясан. Одоо ч гэсэн газрын ихэнх хэсэг өөрчлөгдсөөр байна. Хэрвээ нэгэн өдөр газар дэлхий үнэхээр өөр төрлийнх болж өөрчлөгдвөл, Би үүнийг гараа хөдөлгөх төдийд л хөсөр хаях болно—энэ нь Миний одоогийн үе шатны ажил биш гэж үү? Гэхдээ хүн төрөлхтөнд энэ талаар өчүүхэн төдий ч ойлголт байхгүй; тэд ердөө Миний “удирдамжийн” дор “гэсгээгдэж” байгаа. Үүний юу нь сайн гэж? Би хүнийг гэсгээхийн тулд тодорхой зорилготой ирсэн Бурхан гэж үү? Тэнгэрт Би, хайртай бүх хүн маань Надад ойр байхыг хүсэж, хүмүүсийн дунд байх үедээ тэдэнтэй нэгдэх болно гэж нэгэнтээ төлөвлөсөн. Гэтэл өнөөдөр энэ үе шатанд ирэхэд, хүн надтай холбоо харилцаагүй байгаад зогсохгүй оронд нь Миний гэсгээлтийн улмаас Надаас зай барьдаг. Би тэдний зайгаа барьж байгаагийнх нь төлөө “мэгшин уйлдаггүй.” Юу хийж болох вэ? Хүмүүс бүгд ямар ая тоглож байна тэрийг нь дагаж дуулдаг жүжигчид. Би хүмүүсийг Өөрийн атганаас “мултлах”, үүнээс ч илүүгээр тэднийг “харь нутгаас” Өөрийн “үйлдвэрт” буцаан авчирах чадвартаа итгэлтэй байна. Энэ

зааг дээр хүнд ямар гомдол байж болох вэ? Хүн Надад юу хийж чадах юм бэ? Хүмүүс ханан дээр ургах өвс биш гэж үү? Гэсэн ч энэ алдааных нь төлөө Би хүнийг хорлодоггүй, харин ч оронд нь тэдэнд Өөрийн шим тэжээлийг өгдөг. Хүмүүс сул дорой, хүчин мөхөс, шим тэжээл дутмаг; тэд ийм л байдаг. Би Өөрийн халуун дулаан тэврэлтээр хүний хүйтэн зүрх сэтгэлийг өөрчилдөг, өөр хэн ийм зүйл хийж чадах юм бэ? Би яагаад хүмүүсийн дунд ийм ажил хийсэн юм бэ? Хүн Миний зүрх сэтгэлийг үнэхээр ойлгож чадах уу?

Өөрийн сонгосон бүх хүний дунд Би “наймаа” хийсэн, иймээс Миний гэрт хүмүүс тасралтгүй урсгалаар байнга ирж, явж байдаг. Тэд бүгд Надтай ажил хэрэг хэлэлцэж байгаа мэт Миний байранд янз бүрийн албан хэрэгт оролцож байдаг ба энэ нь Миний ажлыг маш завгүй болгож, заримдаа бүр хүний явган хэрүүлийг зохицуулах ч боломж байдаггүй. Би хүмүүсээс, Миний ачаан дээр ачаа нэмэрлэхгүй байж, Надад байнга найдахын оронд өөрсдийн хөлөг онгоцоо жолоодохыг шаарддаг. Тэд Миний гэрт үргэлж хүүхэд шиг байж болохгүй; тэр нь ямар ашигтай юм бэ? Миний хийдэг зүйл бол чухал ажил хэрэг; Би зүгээр нэг “булангийн хүнсний дэлгүүр” эсвэл “жижиг мухлаг” ажиллуулдаггүй. Хүмүүс Надаар албаар даажигнаж байгаа мэт, чухал асуудлуудыг хэзээ ч тоолгүй, тоглохоос өөр юм боддоггүй муу жаалууд мэт бүгд Миний сэтгэл санааны байдлыг ойлгож чаддаггүй. Тэгсэнээр тэдний олонх нь Миний өгсөн “гэрийн даалгаврыг” хийж чаддаггүй. Тийм хүмүүс хэрхэн “багшдаа” царайгаа харуулж зүрхлэх билээ? Яагаад тэд хийх ёстой зүйлээ хийдэггүй юм бэ? Хүний зүрх сэтгэл гэж ямар янзын зүйл байна аа? Өнөөдрийг хүртэл Надад энэ ойлгомжгүй байна. Яагаад хүмүүсийн зүрх сэтгэл зогсолтгүй өөрчлөгдөж байдаг юм бэ? Тэдний зүрх сэтгэл яг л зургаадугаар сарын өдөр шиг байдаг: нэг бол нар шараад л, нэг бол үүлс нүүгэлтээд л, нэг бол ширүүн салхи исгэрээд л. Тэгвэл хүмүүс яагаад туршлагаасаа суралцаж чаддаггүй юм бэ? Магадгүй Миний хэлсэн хэтрүүлэг байх. Хүмүүс борооны улиралд шүхэр авч гарахаа ч мэддэггүй. Тиймээс өөрсдийнхөө хайхрамжгүй байдлаас болж гэнэт асгарсан бороонд тоо томшгүй олон удаа нэвт норсон бөгөөд Би санаатайгаар тэднээр даажигнаж, тэд үргэлж тэнгэрээс буусан бороонд дарлуулж байгаа мэтээр санадаг. Эсвэл магадгүй Би хэтэрхий “харгис” байж хүмүүсийн анхаарлыг сарниулаад, хэзээ ч юу хийхээ мэддэггүй орон гаран болгочихдог байх. Хэн ч хэзээ ч Миний ажлын зорилго эсвэл ач холбогдлыг үнэхээр ухаарч байгаагүй. Иймээс тэд бүгд өөрсдийгөө сүйдлэх, гэсгээх энэ ажлыг хийж байна. Би тэднийг санаатайгаар гэсгээгээд байгаа юу? Хүмүүс яагаад өөрсөддөө түвэг уддаг юм бэ? Яагаад тэд үргэлж урхи занганд орчихдог юм бэ? Яагаад тэд Надтай “хэлэлцээ хийхгүй”, харин оронд нь өөрсөддөө ажил уддаг юм бэ? Миний хүнд өгч байгаа бүхэн хангалтгүй байна гэж үү?

Би хүн төрөлхтөний дунд Өөрийн “анхны бүтээлийг” хэвлүүлсэн ба Миний бүтээл хүмүүсийн дунд ихээхэн бахдал бишрэл төрүүлж, тэд бүгд үүнийг нарийн, анхааралтай судалж эхэлсэн. Ингэж анхааралтай судалснаар тэд их зүйл олж

авсан. Миний бүтээл эздрээтэй, гайхалтай роман шиг, романтик үргэлжилсэн үгийн шүлэг шиг, улс төрийн хөтөлбөрийн хэлэлцүүлэг шиг, эдийн засгийн эрдэм мэдлэгийн цуглуулга шиг санагддаг. Миний бүтээл маш баялаг болохоор үүний талаар олон өөр санал бодол байдаг бөгөөд Миний бүтээлийг нэгтгэн дүгнэх удиртгал хэн ч бичиж чаддаггүй. Хүмүүс “гоц гойд” мэдлэг, авьяастай байж болох ч Миний энэхүү бүтээл тэдгээр авьяас, чадалтай нөхдүүдийг бүгдийг нь мухардуулахад хангалттай. “Цус урсаж, нулимс асгаруулж болно, гэхдээ хүн толгойгоо гудайлгаж болохгүй” гэж хүмүүс хэлдэг ч тэд Миний бүтээлд бууж өгсний илэрхийлэл болгон өөрсдийн мэдэлгүйгээр толгойгоо гудайлгасан байдаг. Хүн өөрийн туршлагаараа сурсан зүйлээ нэгтгэн дүгнэж, Миний бүтээл нь тэнгэрээс унаад ирсэн тэнгэрлэг ном шиг гэж хэлдэг боловч Би хүнийг хэт эмзэг мэдрэмтгий биш бай гэж ятгадаг. Миний бодлоор, Миний хэлсэн зүйл бол бүгд маш энгийн; гэсэн хэдий ч, Миний бүтээлд орсон “Амьдралын Нэвтэрхий толиос” хүмүүс зарим нэг амьдрах арга замыг олж авч, “Хүний хүрэх газраас” тэд “амьдралын утга учрыг” эрж хайн, “Тэнгэрийн Нууцуудаас” тэд Миний хүслийг эрэлхийлж, “Хүн төрөлхтний Замаас” тэд “амьдрах урлагийг” эрж хайж чадна гэж Би найдаж байна. Ингэснээр бүх зүйл илүү дээр байхгүй гэж үү? Би хүнийг хүчилдэггүй; Миний зохиолыг “сонирхдоггүй” хүмүүсийн хувьд Би тэдэнд Өөрийн номны мөнгөний “буцаалтыг”, дээр нь нэмээд “үйлчилгээний хөлсийг” өгөх болно. Би хэнийг ч хүчилдэггүй. Энэ номын зохиолчийн хувьд Миний ганц найдаж байгаа зүйл бол уншигчид Миний бүтээлд дурлах явдал боловч хүмүүсийн таашаадаг зүйл нь үргэлж өөр байдаг. Иймээс хүмүүс ердөө “нэр төрөө хичээх” үзлээсээ салж зүрхлэхгүйгээсээ болоод ирээдүйгээ баллахгүй бай гэж Би хүмүүсийг ятгадаг. Хэрвээ тийм байсан бол, Би буюу Над шиг сайхан сэтгэлтэй нэгэн тийм их гутамшгийг хэрхэн тэвчиж чадах юм бэ? Хэрвээ чи Миний бүтээлд дурласан нэгэн бол Миний бүтээлийг сайжруулах үүднээс өөрийн үнэ цэнэтэй саналыг Надад илгээж, тэгснээр хүний алдаагаар дамжуулан Би бүтээлийнхээ агуулгыг сайжруулна гэж найдаж байна. Энэ нь зохиолч болон уншигчийн аль алинд тустай, үгүй гэж үү? Миний ингэж хэлж байгаа нь зөв эсэхийг мэдэхгүй, магадгүй энэ маягаар Би бичих чадвараа сайжруулж чадна, эсвэл магадгүй өөрсдийн нөхөрлөлийг бэхжүүлж чадна. Үндсэндээ, бүх хүн Миний ажилд саад бололгүй хамтран ажиллаж, ингэснээр Миний үг бүх гэр бүл, айлуудад тархаж, газар дээрх бүх хүн Миний үгэнд амьдарч чадна гэж Би найдаж байна. Энэ бол Миний зорилго. Миний үгийн Амийн тухай Бүлгийг уншсанаар бүх хүн ямар нэг юм олж авч, ялангуяа амьдралын тухай зарчим эсвэл хүн төрөлхтөнд тохиолдох алдааны тухай мэдлэг эсвэл Би хүнээс юу шаарддагийг эсвэл өнөөдрийн хаанчлалын хүмүүсийн “нууцуудыг” олж авна гэж Би найдаж байна. Гэсэн хэдий ч Би “Өнөөдрийн Хүний Гутамшигт Явдлуудыг” хар гэж хүмүүсийг ятгадаг; энэ нь бүгдэд ач тустай байж чадна. Түүнчлэн хүмүүсийн аминд бүр ч илүү их тустай байж болох “Хамгийн Сүүлийн Нууцыг” уншчихад ч гэмгүй. Мөн “Халуун Сэдвүүд” хэсгийг байнга уншиж бай—энэ нь хүмүүсийн аминд бүр ч илүү ач тустай

биш гэж үү? Миний “зөвлөгөөг” ашиглаж, ямар нэгэн үр нөлөөтэй эсэхийг хараад, үүнийг уншсаныхаа дараа Надад өөрийн сэтгэгдлээ хуваалцах нь ямар ч гэм хоргүй. Ингэснээр Би зөв эмийн жор бичиж, эцэст нь хүн төрөлхтний өвчин эмгэгийг бүрмөсөн арилгаж чадах юм. Миний саналын талаар юу гэж бодож байгааг чинь Би мэдэхгүй байна, гэхдээ чи тэдгээрийг лавлах материал гэж хараасай гэж Би найдаж байна. Ингэвэл ямар байна?

1992 оны 5 дугаар сарын 12

42-Р БҮЛЭГ

Шинэ ажил эхэлмэгц бүх хүнд шинэ оролт байх ба тэд Надтай хамт гар гараасаа хөтлөлцөн урагшилна. Бид хаанчлалын агуу замаар хамтдаа алхдаг, хүн бид хоёр хоорондоо асар дотно байдаг. Өөрийнхөө мэдрэмжийг харуулахын тулд, хүнд хандах Өөрийнхөө хандлагыг үзүүлэхийн тулд Би хүнтэй үргэлж ярьж ирсэн. Гэхдээ эдгээр үгээс зарим нь хүмүүсийг гомдоож болох ч зарим нь тэдэнд асар их ач тустай байж магадгүй, иймээс Миний амнаас гардаг үгийг илүү олон удаа сонс гэж Би хүмүүст зөвлөдөг. Миний айлдварууд нэн гоёмсог биш байж магадгүй боловч тэдгээр нь бүгд Миний зүрх сэтгэлийн гүнээс гарсан үг юм. Хүн төрөлхтөн Миний найз нөхөр учраас Би Өөрийн ажлыг хүмүүсийн дунд үргэлжлүүлэн гүйцэтгэсэн ба хүн ч гэсэн Миний ажлыг тасалдуулахаас ихэд айж, Надтай хамтран ажиллахын тулд чадах бүхнээ хийдэг. Энэ мөчид Миний зүрх сэтгэл асар их баяр хөөрөөр дүүрэн байна, учир нь Би хэсэг хүмүүсийг олж авсан бөгөөд иймээс Миний “бизнес” уналтад байхаа больж, хий хоосон үг байхаа больж, Миний “тусгай бүтээгдэхүүний зах зээл” муухан ажилладгаа больж байна. Эцсийн эцэст хүмүүс ухаалаг байж—Миний нэр, Миний алдрын төлөө бүгд “өөрсдийгөө зориулахад” бэлэн байгаа бөгөөд зөвхөн ийм маягаар Миний “тусгай дэлгүүр” зарим нэг шинэ “бараа” олж авдаг учраас сүнсний ертөнц дэх олон “үйлчлүүлэгч” Миний “барааг” худалдан авахаар ирдэг. Зөвхөн энэ мөчөөс эхлэн Би алдрыг олж авдаг; зөвхөн тэгэхэд л Миний амнаас гарсан үг хоосон үг байхаа больдог. Би ялалт байгуулж, ялалттайгаар эргэн ирсэн бөгөөд бүх хүн Намайг алдаршуулан тэмдэглэдэг. Намайг биширдгээ харуулж, Миний хөлд бууж өгсөн гэдгээ харуулахын тулд энэ мөчид агуу улаан луу ч гэсэн “тэмдэглэхээр” ирдэг ба үүнийг Би алдар суу гэж хардаг. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Би олон ялгуусан тулаанд тулалдсан бөгөөд олон биширмээр зүйл хийсэн. Олон хүн нэгэнтээ Намайг тэмдэглэж, Надад магтаал өргөж, Миний төлөө бүжиглэсэн. Эдгээр нь хэдийгээр сэтгэл хөдлөм, мартагдашгүй дүр зураг байсан боловч Би хэзээ ч инээмсэглэлээ харуулаагүй, учир нь Би хүнийг хараахан байлдан дагуулаагүй, ердөө л орчлон ертөнцийг бүтээсэнтэй төстэй ажлын нэг хэсгийг л хийж байлаа. Өнөөдөр бол өнгөрсөн үетэй

адилгүй. Би сэнтий дээрээс инээмсэглэдэг, Би хүнийг байлдан дагуулж, хүмүүс бүгд Миний өмнө толгой бөхийж шүтэн мөргөдөг. Өнөөдрийн хүмүүс бол урьдын хүмүүс биш. Миний ажил өнөө үеэс өөр юмны төлөө байсан байж болно гэж үү? Энэ нь Миний алдраас өөр юмны төлөө байсан байж болно гэж үү? Илүү гэгээлэг маргаашийн төлөө, хүнд хийдэг бүх ажлаа Би бүр илүү ил тод болгоно, ингэснээр Миний бүхий л алдар бүтээгдсэн хүнд “амарч” магад. Би үүнийг Өөрийн ажлын зарчим болгоно. Надтай хамтран ажиллахад бэлэн хүмүүс өндийн босож, шаргуу ажилла, ингэснээр Миний алдар улам ихээр огторгуйг дүүргэж болох юм. Одоо үе бол асар том төлөвлөгөөг хэрэгжүүлэх цаг. Миний хайрын халамж, хамгаалалт дор байдаг бүхэнд авьяас чадвараа Надтай хамт энд хэрэглэх боломж байгаа бөгөөд Би бүх зүйлийг Өөрийнхөө ажлын төлөө “эргэлдүүлэхийн” тулд зална. Тэнгэрт нисэж буй шувууд бол тэнгэр дэх Миний алдар, газар дээрх далай тэнгис бол газар дээрх Миний үйлс, бүх зүйлийн эзэн бол бүх зүйлийн дундах Миний илрэл бөгөөд Би газар дээр байгаа бүхнийг Өөрийн удирдлагын хөрөнгө болгон хэрэглэж, бүх зүйлийг үржин олширч, цэцэглэн хөгжиж, амиар гэрэлтэхэд хүргэдэг.

Газар дээрх Миний ажил эцсийн үе шатанд бүрэн төгсөнө гэж Би бүтээлийн цаг үед аль хэдийн шийдсэн. Миний ажил дуусах үе нь Миний бүх үйлс огторгуйд илэрхий болох яг тэр үе байх болно. Би газар дээрх хүмүүсээр Өөрийн үйлсийг хүлээн зөвшөөрүүлж, “шүүлтийн ширээний” өмнө Миний үйл хэргүүд нотлогдоно, ингэснээр газар дэлхий даяар хүмүүсийн дунд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тэд бүгд бууж өгнө. Тийнхүү дараа нь Би өнгөрсөн эрин үеүдэд хэзээ ч хийгдэж байгаагүй төслийг эхлүүлнэ. Өнөөдрөөс эхлээд Би Өөрийн үйл хэргийг алхам алхмаар ил болгоно, ингэснээр Миний мэргэн ухаан, Миний гайхалтай байдал болон Миний ойлгогдошгүй байдал нийгмийн бүхий л хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж, нотлогдох юм. Миний үйлс “шүүгчээр” шүүгдэж, “хуульчаар” “өмгөөлүүлэхүйц” хэмжээнд байх ёстой учир ялангуяа газар дээрх бүх эрх баригч нам Миний үйл хэргийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болно, тиймээс Миний үйлс хүлээн зөвшөөрөгдөж, бүх хүн толгой гудайн, буулт хийхээс аргагүй болно. Энэ цаг мөчөөс эхлээд Миний үйлдлүүд нийгмийн бүх хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх ба энэ нь газар дээр бүх алдрыг Би олж авах мөч байх болно. Тэр үед Би хүнд илрэн харагдах бөгөөд цаашид нуугдахгүй. Одоохондоо Миний үйл хэрэг оргилдоо хараахан хүрээгүй байна. Миний ажил урагш ахисаар байгаа бөгөөд дээд цэгтээ хүрээд дуусах юм. Би бүх улс үндэстний хүмүүсийг бүрэн байлдан дагуулж, догшин араатнуудыг Өөрийнхөө өмнө хурга шиг номхон болгож, газар дээрх хүмүүсийн адилаар агуу улаан лууг Миний өмнө захирагдахад хүргэнэ. Би тэнгэр дэх бүх дайснаа ялан дийлж, газар дээрх бүх өрсөлдөгчөө ч байлдан дагуулагдахад хүргэнэ. Энэ бол Миний төлөвлөгөө, Миний үйл хэргийн гайхалтай байдал юм. Хүн Миний удирдамж доор байгалийн нөлөөнд л амьдарч чадна—тэр өөрөө шийдвэр гаргаж чадахгүй! Хэн Миний мутраас зугтаж чадах юм бэ? Би бүхий л байгалийг янз бүрийн ангилалд хуваарилж, хуулийн дотор оршин байлгаж байгаа бөгөөд

чухам ийм учраас л газар дээр хаврын урь, намрын сэрүү гэх мэтийн хуулиуд байдаг. Газар дээрх цэцэгс өвөл хагдарч, зун цэцэглэдгийн шалтгаан нь Миний мутрын гайхалтай байдлаас болдог; галуун сүрэг өвөлдөө өмнө зүгт нисдэгийн шалтгаан нь Би халуун хүйтнийг тохируулдгаас болдог; мөн далай тэнгис давалгаалдгийн шалтгаан нь усны гадаргуу дээрх зүйлсийг усанд автуулахыг Би хүсдэгээс болдог. Миний зохицуулдаггүй юу байна вэ? Энэ мөчөөс эхлээд хүний “байгалийн эдийн засаг” Миний үгэнд бүхэлдээ ялагдаж, “байгалийн хууль” байгаа учраас хүмүүс Миний оршин байгааг бүрэн устгахаа болино. Бүх зүйлийн Захирагчийн оршин тогтнолыг хэн дахин үгүйсгэж зүрхлэх юм бэ? Тэнгэрт Би бол Тэргүүн нь; бүх зүйлийн дунд Би бол Эзэн; бүх хүний дунд Би нэгдүгээрх нь. Үүнийг “будгаар” хөнгөн дарж хэн зүрхлэх юм бэ? Үнэний оршин тогтнолыг худал хуурмаг тасалдуулж чадах уу? Энэхүү үнэ цэнтэй боломжоор Би Өөрийн гар дахь ажлыг дахин нэгэнтээ эхэлж, цаашид хүний хөндлөнгийн оролцоог амсахгүй, машиныг үргэлжлүүлэн “эргүүлнэ”.

Би Өөрийнхөө үгэнд янз бүрийн “амтлагч” нэмсэн, тиймээс Би хүн төрөлхтний гарамгай тогооч нарын нэг нь юм шиг санагдах болно. Хэдийгээр хүмүүс хоолоо яаж амтлахаа мэддэггүй боловч тэд амтанд нь дурладаг; тэд “тавгаа” бариад Миний бэлтгэсэн “хоолнуудыг” бүгд амтархан иддэг. Яагаад гэдгийг нь мэдэхгүй ч хүмүүс Миний биечлэн бэлтгэсэн хоолыг илүү их идэхийг үргэлж хүсдэг. Тэд Намайг хэтэрхий өндрөөр үнэлдэг, Намайг бүх амтлагчаас хамгийн шилдэг нь гэж хардаг юм шиг байдаг бөгөөд бусад хүнийг огтхон ч тоодоггүй. Миний өөрийгөө хүндлэх сэтгэл дэндүү их учраас хувийн шалтгаанаар бусдын “найдвартай ажлын байрыг” бут ниргэхийг хүсдэггүй. Тиймээс Би боломжийг ашиглан “гал тогооноос” холдож, өөрийгөө харуулах боломжийг бусдад олгодог. Зөвхөн ийм байдлаар л Миний зүрх сэтгэл тууштай байдаг; хүмүүсээр Өөрийгөө хүндлүүлж, бусдыг дорд үзүүлэхийг Би хүсдэггүй; тэр бол буруу юм. Хүмүүсийн зүрх сэтгэлд байр суурь эзлэхийн үнэ цэн юу вэ? Би үнэхээр тийм бүдүүлэг, бодлогогүй гэж үү? Би үнэхээр байр суурь шаардахад бэлэн гэж үү? Хэрвээ тийм юм бол яагаад Би ийм агуу төслийг эхлүүлдэг юм бэ? Би алдар нэр, эд хөрөнгийн төлөө бусадтай тэмцэхийг хүсдэггүй, Би хорвоогийн алдар нэр болон эд хөрөнгийг үл тоомсорлодог; энэ Миний эрэлхийлдэг зүйл биш. Би хүнийг үлгэр дуурайл гэж хардаггүй, Би тэмцэлдэж, эсвэл шүүрч булаадаггүй, харин Би “ур чадвартаа” дулдуйдаж амьдралаа залгуулдаг бөгөөд мөс чанаргүй үйл хийдэггүй. Тиймээс газар дэлхийгээр алхах үедээ Би эхлээд үйлдээд дараа нь “гар урлалынхаа төлбөрийг” шаарддаг—зөвхөн энэ л хүний хэлдэг шударга ёс, зүйтэй байдал юм. Үүнд ямар ч хэтрүүлэг байхгүй, бас байгаагаас нь өчүүхэн төдий ч дор болгож яриагүй; Би баримтуудын жинхэнэ утга учрын дагуу л ярьдаг. Би хүмүүсийн дунд нааш цааш явж, шударга агаад боломжийн хүмүүсийг эрж хайдаг ч ямар ч үр дүн гарсангүй. Хүмүүс наймаацах дуртай учраас үнэ нь нэг бол хэтэрхий өндөр, эсвэл хэтэрхий доогуур байдаг, иймээс Би “Надад оногдсон” гарт байгаа ажлаа хийсээр л байна.

Өнөөдөр хүн яагаад үүргээ мөрддөггүйг, өөрийнх нь биеийн хэмжээ хэр том болохыг яагаад мэддэггүйг Би бас л мэдэхгүй байна. Биеийн хэмжээ нь хэдэн грамм уу, эсвэл хэдэн лиан[a] уу гэдгийг ч хүмүүс мэддэггүй. Тиймээс тэд Намайг аргалсаар байдаг. Миний бүх ажил талаар болсон мэт, Миний үг өндөр уулан дахь цуурай мэт байдаг бөгөөд Миний үг болон айлдваруудын үндсийг хэн ч, хэзээ ч ухамсарлаагүй. Иймээс Би гурав дахь онч мэргэн үгийг товч дүгнэж хэлэхдээ үүнийг суурь болгон ашигладаг: “Хүмүүс Намайг мэддэггүй, учир нь тэд Намайг хардаггүй”. Энэ нь, Миний үгийг идчихээд хүмүүс хоолны шингэцийг сайжруулах гэж эм уудаг ба эмийн гаж нөлөө хэтэрхий хүчтэй болохоор тэд ой санамжаа алдаад Миний үг мартагдаж, Миний байгаа газар тэдний мартсан булан болдог мэт байдаг. Үүнээс болж Би санаа алддаг. Би маш их ажил хийсэн атал яагаад үүний баталгаа хүмүүст байдаггүй юм бэ? Би хангалттай хичээл чармайлт гаргаагүй гэж үү? Эсвэл хүнд юу хэрэгтэйг Би ухаараагүй учраас тэр үү? Би энэ талаар юу ч хийгээд хэрэггүй болсон, Миний цорын ганц сонголт бол Өөрийн захиргааны зарлигийг ашиглан бүх хүнийг байлдан дагуулах юм. Би элбэрэлт эх байхаа болиод бүх хүн төрөлхтнийг хатуу эцгийн ёсоор удирдах болно!

1992 оны 5 дугаар сарын 15

43-Р БҮЛЭГ

Миний захиргааны зарлигаас л болоод хүмүүс Миний үгийг “ихээхэн сонирхох” болсон байх. Тэд Миний захиргааны зарлигт захирагддаггүй байсан бол бүгд л үргэсэн барс шиг архирах байсан. Би өдөр бүр үүлэн дунд хэсүүчилж, дэлхийг бүрхэн буй хүн төрөлхтөн Миний захиргааны зарлигийн дагуу Миний хориг дор бужигналдахыг хардаг. Ингэж хүн төрөлхтнийг дэг журамтай байлгаж, захиргааны зарлигаа Би мөнхжүүлдэг. Энэ цаг үеэс эхлэн Миний захиргааны зарлигаас болж газар дээрх хүмүүс бүх төрлийн гэсгээлтийг хүртэх бөгөөд энэхүү гэсгээлт тэдэн дээр бууж ирэхэд бүх хүн чангаар орилолдон, зүг бүрд зугтдаг. Энэ мөчид газрын улс үндэстнүүд даруй мөхөж, улс үндэстний хоорондын зааг үгүй болж, газар нутгийг хуваахаа больж, хүмүүсийн хооронд хагацал байхаа болино. Хүмүүс нэг нэгэнтэйгээ эв найрамдалтай зэрэгцэн оршиж, цаашид дайтахгүй байгаасай гэсэндээ Би хүмүүсийн хооронд “үзэл суртлын ажил” хийж эхэлдэг бөгөөд Намайг хүн төрөлхтний дунд гүүр барьж, холбоо тогтооход хүмүүс нэгдмэл болдог. Би дээд тэнгэрийг Өөрийн үйлийн илрэлээр дүүргэж, газар дээрх бүх зүйлийг Өөрийн хүч чадлын дор унагаан мөргүүлж, тийнхүү “дэлхийн эв нэгдлийн” төлөөх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэн, Өөрийн энэ хүслийг биелүүлэх болно. Ингэснээр хүн

[a] “Лиан” гэдэг нь Хятадын жингийн хэмжүүр; нэг лиан 50 граммтай тэнцүү.

газрын хөрсөн дээр “тэнүүчлэхээ” больж, харин тохиромжтой хүрэх газрыг саадгүй олно. Би хүн төрөлхтний төлөө бүхий л талаар санаа тавьдаг бөгөөд ингэснээр удахгүй хүн төрөлхтөн амар амгалан, аз жаргалын оронд амьдарч, тэдний амьдралын өдрүүд гунигтай, хоосон байхаа больж, Миний төлөвлөгөө газар дээр бүтэлгүйтэхгүй. Хүн тэнд оршин байдаг учраас Би Өөрийн улс орныг газар дээр байгуулах болно. Учир нь Миний алдрын нэг хэсэг газар дээр илэрдэг юм. Дээр тэнгэр дэх Өөрийн хотыг зөв зүйтэй болгож, тэгснээрээ дээр дооргүй бүх зүйлийг шинэчилнэ. Би тэнгэрийн дээр болон доор орших бүхнийг нэгтгэх болно. Ингэснээр газар дээрх бүх зүйл тэнгэр дээрх бүх зүйлтэй нэгдэнэ. Энэ бол Миний төлөвлөгөө; энэ бол миний эцсийн эринд биелүүлэх ёстой зүйл юм—Миний ажлын энэ хэсэгт хөндлөнгөөс оролцохыг хэнд ч зөвшөөрч болохгүй! Харь үндэстнүүдийн дунд ажлаа түгээх нь газар дээрх Миний ажлын сүүлийн хэсэг юм. Миний хийх ажлыг хэн ч ойлгож чаддаггүй бөгөөд үүнээс болж хүмүүс ихэд төрөөлддөг. Би газар дээр ажлаа хийгээд завгүй байдаг болохоор хүмүүс боломжийг ашиглаад “зугаацдаг”. Хэтэрхий дэг журамгүй болохоос нь сэргийлж, Би эхлээд тэднийг Өөрийн гэсгээлтэд оруулж галт нуурын сахилгажуулалтыг туулуулсан. Энэ бол Миний ажлын нэг алхам бөгөөд ажлынхаа энэ алхмыг биелүүлэхийн тулд Би галт нуурын хүчийг ашиглах болно; эс бөгөөс Өөрийн ажлыг гүйцэтгэх боломжгүй байх болно. Би орчлон даяарх хүмүүсийг Өөрийн сэнтийн өмнө захирагддаг болгож, шүүлтийнхээ дагуу өөр өөр ангилалд хуваж, эдгээр ангиллын дагуу ялгаж, улмаар гэр бүлүүдээр нь ангилна. Ингэснээр бүх хүн төрөлхтөн Надад дуулгаваргүй байхаа больж, харин ч миний нэрлэсэн ангиллын дагуу дэг журамтай, цэгцтэй зохицуулалтад орох болно—хэн ч санаан зоргоор нүүж үл болно! Орчлон даяар Би шинэ ажил хийлээ; Миний гэнэтийн илрэлт орчлон даяар бүх хүнийг алмайруулан гайхшируулж, Миний тод илрэлт тэдний мэдлэгийн хүрээг үлэмж тэлсэн. Өнөөдөр тийм биш байна гэж үү?

Би бүх улс үндэстэн, ард түмний дунд анхны алхалтаа хийж, ажлынхаа эхний хэсгийг эхлүүллээ. Би шинээр эхлэх төлөвлөгөөгөө тасалдуулахгүй: Харь үндэстнүүдийн дунд хийх ажлын дараалал нь тэнгэр дэх Миний ажлын горим дээр үндэслэдэг юм. Миний үйл хөдлөл, үйлдэл бүрийг харахаар бүх хүн дээшээ харах тэр үед Би дэлхий дээр манан буулгадаг. Хүмүүсийн нүд тэр даруйд сүүмийж, эзгүй цөлд байгаа хонь шиг зүг чигээ алдах бөгөөд шуурга исгэрч эхлэхэд тэдний хашхираан исгэрэх салхины чимээнд дарагдана. Шуурган дунд хүний дүрс сүүмийн харагдах боловч дуу нь сонсогдохгүй бөгөөд хүмүүс хамаг чадлаараа хашхирлаа ч хүчин чармайлт нь талаар өнгөрдөг. Энэ үед хүн тэнгэрээс гэнэт аврагч бууж ирэн, тэднийг удирдан хил хязгаар нь үл харагдах цөлөөс гаргана хэмээн найдаж, чангаар цурхиран уйлдаг. Гэвч тэдний итгэл хэчнээн агуу байгаад ч аврагч хөдлөхгүй л байх бөгөөд хүний итгэл найдвар тасарна: Асаасан итгэлийн галыг цөлийн шуурга бөхөөж, хүн хоосон, эзгүй газарт навтайн унаад дахин хэзээ ч дүрэлзсэн бамбар өргөлгүй, ухаан алдана… Энэ мөчийг ашиглан Би хүний нүдний

өмнө нэгэн баян бүрдийг ил болгодог. Гэвч хүний зүрх сэтгэлийн нар нь гарч болох ч бие нь хариу үйлдэл үзүүлэхэд хэтэрхий ядруу, сул дорой, хөлөө арай ядан чирч байдаг; баян бүрдэд ургах сайхан жимсийг хараад ч тасалж идэх чадалгүй байдаг, учир нь хүний “дотоод нөөц” бүрэн шавхагджээ. Би хэрэгцээтэй зүйлийг нь хүнд аваад өгөхөд царай нь ямар ч баяр баясалгүй, зэрвэсхэн инээмсэглэл тодруулаад л өнгөрнө: Хүний хүч тэнхээ нь ул мөргүй алга болж, агаарын урсгалд туугдан оджээ. Энэ шалтгааны улмаас хүний царай ямар ч хувиралгүй байж, зөвхөн цус хурсан нүднээс нь эх хүн үрээ харж байгаа юм шиг энэрэл агуулсан хайрын ганц туяа цацарна. Ярих гээд ярих тэнхээгүй байгаа мэт омголтож, хагарсан уруул нь үе үе хөдөлнө. Би түүнд ус өгөх ч тэрээр дэмий л толгойгоо сэгсэрнэ. Эдгээр хачин жигтэй, урьдчилан таамаглашгүй үйлдлээс нь хүн өөрөө өөртөө итгэх бүх итгэл найдвараа аль хэдийн алдаад, ямар нэг юм гуйж буй мэт тусламж эрсэн харцаар гагцхүү Намайг ширтэж буйг нь Би ойлгодог. Гэвч хүн төрөлхтний ёс заншлыг мэдэхгүй Би хүний нүүрний хувирал, үйлдлийг хараад гайхширдаг. Зөвхөн энэ мөчид хүний оршихуйн эцсийн өдрүүд даруй ойртож байгааг гэнэт олж мэдээд Би түүн рүү өрөвдсөн харцаар харна. Тэр мөчид л хүн над руу бүх хүсэл нь биелсэн мэт сэтгэл хангалуун инээмсэглэл тодруулаад толгой дохино. Хүн гуниглахаа больж; газар дээр хүмүүс амьдралын хоосон байдлын талаар гомдоллохоо болиод, “амьдрал”-тай харьцах бүх харьцалтаа тэвчинэ. Үүнээс хойш газар дээр дахин санаа алдахаа байж, хүн төрөлхтний амьдралын өдрүүд цэнгэлээр дүүрнэ…

Би Өөрийн ажлыг эхлэхээс өмнө хүний хэрэг явдлыг зохих ёсоор зохицуулна, тэгвэл хүн Миний ажилд байнга садаа болоод байхгүй. Миний хувьд, хүний хэрэг явдал гол асуудал биш; хүн төрөлхтний хэрэг явдал ялихгүй. Хүн өчүүхэн сэтгэлтэй учраас шоргоолжинд хүртэл өршөөл үзүүлэхийг хүсэхгүй, шоргоолж хүн төрөлхтний дайсан юм шиг харагддаг—хүмүүсийн дунд үргэлж зөрчил байдаг. Хүмүүсийн зөрчлийг сонсоод би дахин нэг удаа холдон явж, тэдний түүхийг анхаарахаа больдог. Хүний нүдэнд Би бол “оршин суугчдын” дундах “гэр бүлийн маргаан”-ыг шийдвэрлэх чиглэлээр мэргэшсэн “оршин суугчдын холбоо” юм. Хүмүүс Миний өмнө ирэхдээ үргэлж өөрсдийн шалтгаантай ирдэг бөгөөд тэд түрэмгий хүслээрээ “ер бусын туршлагаа” хүүрнэж, өөрсдийн тайлбараар нэмж хачирладаг. Би хүний ер бусын зан байдлыг харж байна: нүүр царай нь тоосонд дарагдсан байх ба тэрхүү тоос нь хөлсний “урсгал” дор хөлстэй холилдмогц “салангид чанар”-аа алдаад, хааяахан хөлийн мөр харагдах далайн элсэрхэг эрэг мэт хүмүүсийн царайг улам “чимэх” аж. Тэдний үс нь хий үзэгдлийг санагдуулам өнгө зүсгүй байх ба газарт шигдсэн сүрэл шиг арзайж боссон байдалтай байна. Түүний уур хилэн дүрэлзэх тул улангассандаа үс нь сэгсийж, хөлс нь “буцалж” байгаа мэт царайнаас нь үе үе “уур” савсана. Ойроос шинжин харвал хүний нүүр царай яг л улалзах нар шиг “галын дөл”-өөр бүрхэгдсэн байх аж. Тиймээс нүүрнээс нь халуун хий дэгдэх бөгөөд нүүр царайгаа уур хилэнгийнхээ золиос болгох вий гэж Би үнэхээр санаа зововч тэрээр өөрөө тоосон шинжгүй байх аж. Энэ үед Би хүнийг уур хилэнгээ бага зэрэг дарахыг

ятгадаг. Учир нь энэ юунд ашигтай гэж? Өөрийгөө юунд ингэж тамлан зовооно вэ? Уур хилэнгийн улмаас дэлхийн гадаргуу дээрх сүрлийн ишнүүд нарны дөлөнд шатаж дуусдаг. Ийм нөхцөлд “сар” хүртэл улайдаг. Би хүнд уур хилэнгээ тогтоон барихыг ятгадаг—түүнд эрүүл мэндээ хамгаалах нь чухал юм. Гэвч хүн Миний зөвлөгөөг сонсдоггүй; харин ч Надад “гомдол мэдүүлсээр” байдаг. Энэ юунд хэрэгтэй гэж? Миний өгөөмөр бэлгийг эдлэх хүмүүст хангалтгүй байна гэж үү? Эсвэл хүн Миний өгдөг зүйлээс татгалздаг хэрэг үү? Гэнэт уцаар төрөн Би ширээг авч шидэх бөгөөд хүн өөрийн түүхийн сэтгэл хөдөлгөм хэсгүүдийг ярьж зүрхлэхээ больдог; өөрийг нь хэд хоног саатуулахаар “цагдан хорих төв” рүү авч явах вий хэмээн айж, Миний уцааршаас үүдсэн боломжийг ашиглан, зугтаж алга болдог. Бусад тохиолдолд хүн хэзээ ч ийм зүйлийг орхихыг хүсэхгүй, харин өөрийн зовнилын талаар чалчсаар байх байсан. Энэ талаар сонсоход л Миний уур хүрч байна. Хүн зүрх сэтгэлийнхээ гүнд яагаад ийм төвөгтэй байдаг юм бэ? Би хүний дотор хэтэрхий олон “эд анги” суулгачихсан юм болов уу? Тэр яагаад үргэлж Миний өмнө жүжиг тоглодог юм бэ? Би “иргэний маргаан” шийдвэрлэх “зөвлөх” биш байлтай? Би хүнээс над дээр ирэхийг гуйсан бил үү? Би мужийн шүүгч биш байлтай? Хүмүүсийн хэрэг явдлыг яагаад үргэлж Миний өмнө авчирдаг юм бэ? Хүн өөрөө өөрийгөө аваад явчих чадалтайгаа ойлгоод Надад саад болохгүй байх болов уу гэж Би найдаж байна, учир нь надад хийх ажил их байна.

1992 оны 5 дугаар сарын 18

44-Р БҮЛЭГ

Хүмүүс Миний ажлыг нэмэлт зүйл гэж үздэг; тэд үүний төлөө нойр, хоолоо умартдаггүй тул Надад хандах хандлагад нь тохирсон шаардлагыг хүнд тавихаас өөр сонголт Надад үгүй. Нэгэнтээ Би хүнд ихээхэн нигүүлсэл, олон ерөөл хүртээсэн боловч эдгээр зүйлийг булаан авсныхаа дараа тэрээр даруйхан яваад өгснийг Би санаж байна. Би тэдгээрийг хүнд санаандгүй өгсөн мэт байсан юм. Тиймээс хүн өөрийн үзлийг ашиглан Намайг үргэлж хайрласан. Хүн Намайг үнэхээр хайрлаасай гэж Би хүсдэг, гэвч өнөөдөр хүмүүс цаг нөхцөөсөөр жинхэнэ хайраа Надад өгч чаддаггүй. Надад жинхэнэ хайраа өгчих юм бол өөрсдөө юу ч үгүй хоосон хоцорно гэж тэд төсөөлөлдөө боддог. Намайг дургүйцэхэд тэдний хамаг бие дагждаг—тэгсэн атлаа Надад жинхэнэ хайраа өгөхийг хүсэхгүй хэвээр үлддэг. Тэд ямар нэгэн зүйл хүлээж байгаа мэт байдаг тул урагшаа харан, чухам юу тохиолдоод байгааг Надад ерөөсөө хэлдэггүй. Тэд амаа үдүүлчихсэн мэт байдаг болохоор ярихдаа байнга ээрч түгдэрдэг. Хүний өмнө Би харгис капиталист болсон мэт санагддаг. Хүмүүс Надаас үргэлж эмээдэг: Миний бараанаар тэд нэн даруй ул мөргүй алга болж, Намайг өөрсдийнх нь нөхцөл байдлын талаар асуух вий гэж үхтлээ айдаг.

Хүмүүс “нэг тосгоныхныгоо” чин сэтгэлээс хайрлаж чаддаг мөртөө сүнсээрээ шулуун шударга Намайг яагаад хайрладаггүйг Би мэдэхгүй. Үүнээс болж Би шүүрс алддаг: Хүмүүс яагаад өөрсдийнхөө хайрыг үргэлж хүний ертөнцөд гаргадаг юм бэ? Яагаад Би хүний хайрыг амсаж чаддаггүй юм бэ? Би хүн төрөлхтний нэг биш учраас тэр үү? Хүмүүс Намайг үргэлж уулын зэрлэг хүн шиг авч үздэг. Хэвийн хүнийг бүрдүүлдэг бүх хэсэг Надад дутагддаг мэт байдаг тул Миний өмнө хүмүүс үргэлж өндөр ёс суртахуунтай дүр үзүүлдэг. Тэд Намайг зэмлэхийн тулд үргэлж өмнөө чирч авчраад цэцэрлэгийн насны хүүхдийг загнадаг шигээ Намайг загнадаг; хүмүүсийн ой дурсамжид бол Би ухвар мөчид, боловсролгүй нэгэн учраас хүмүүс Миний өмнө дандаа сурган хүмүүжүүлэгчийн дүрд тоглодог. Би бүтэлгүйтсэнийх нь төлөө хүмүүсийг гэсгээдэггүй, харин тэдэнд тохиромжтой туслалцаа үзүүлж, байнгын “эдийн засгийн тусламж” хүртээдэг. Хүн үргэлж гай зовлон дунд амьдарч, үүнээс зайлсхийхэд хэцүү байсан учраас энэ гай гамшгийн дунд Намайг үргэлж дууддаг байсан ба Би “үр тарианы хангамжийг” түүний гарт цагт нь хүргэн, бүх хүнийг шинэ эриний асар том гэр бүлд амьдруулж, асар том гэр бүлийн халуун дулааныг мэдрүүлдэг. Би хүмүүсийн дундах ажлыг ажиглаад хүний олон дутагдлыг олж илрүүлсэн ба тэгсний үр дүнд Би хүнд тусалдаг. Одоо ч гэсэн хүмүүсийн дунд жигтэйхэн ядуурал байсаар байгаа тул Би “үгээгүй хоосон газруудад” зохистой халамж хүртээж, ядуурлаас дээш татсан. Өөрийн нигүүлслийг бүх хүнд аль болох их эдлүүлэх нь Миний ажилладаг арга барил юм.

Газар дээрх хүмүүс өөрийн мэдэлгүй гэсгээлт амсдаг тул Би асар том гараа дэлгэж, тэднийг хажуудаа татан авчраад, газар дээр Миний нигүүлслийг эдлэх сайн хувь заяаг тэдэнд олгодог. Газар дээрх юу хоосон бус, үнэ цэнгүй биш байдаг вэ? Би хүний ертөнцөд бүх газар нутгаар алхдаг бөгөөд алдарт хөшөө дурсгал, байгалийн аятай таатай үзэсгэлэнт газар үй олон байдаг хэдий ч Миний очсон газар бүр аль хэдийн эрч хүчгүй болчихсон байлаа. Газар дэлхий бүрхэг, хоосон гэдгийг тэгэхэд л Би мэдэрсэн: Газар дээрх амьдрал аль эрт үгүй болчихсон. Гагцхүү үхлийн үнэр л байсан учраас Би зовлонгийн энэ газрыг хурдхан орхиж яв гэж хүнийг үргэлж дуудаж байлаа. Миний харсан бүхнээс хоосон байдал ханхалж байв. Би боломжийг ашиглан Өөрийнхөө сонгосон хүмүүст гартаа буй амийг чулуудаж өгсөн; тэр даруй газар дээр нэгэн ногоон талбай бий болсон. Хүмүүс газар дээрх амин чанартай зүйлсийг эдлэхэд бэлэн байдаг ч Би үүнээс ямар ч таашаал авдаггүй; хүмүүс газар дээрх юмсыг үргэлж нандигнадаг бөгөөд хоосон байдлыг нь хэзээ ч олж хардаггүй болохоор өнөөдөр энэ цэгт хүрчхээд газар дээр яагаад ямар ч амьдрал байдаггүйг бас л ойлгодоггүй. Өнөөдөр Намайг орчлон ертөнцөөр алхаж явахад бүх хүн Миний байгаа газрын нигүүлслийг хүртэж чаддаг бөгөөд тэд үүнийг хөрөнгө болгон ашиглаад, амьдралын эх сурвалжийг хэзээ ч эрэлхийлдэггүй. Тэд Миний өгсөн зүйлийг хөрөнгө болгон ашигладаг атлаа тэдний нэг нь ч амин чанарын анхдагч чиг үүргийг гүйцэтгэхээр хичээдэггүй. Тэд байгалийн нөөцийг хэрхэн ашиглаж, хөгжүүлэхээ мэддэггүй болохоор ядуу зүдүү болсон. Би

хүмүүсийн дунд оршин сууж, хүмүүсийн дунд амьдардаг атал хүн Намайг одоо ч мэддэггүй. Гэрээсээ маш их хол байгаагаас минь болоод хүмүүс Надад ихээхэн тусалсан хэдий ч Би хүнтэй зөв барилдлага хараахан тогтоогоогүй мэт байдаг болохоор хүний ертөнцийн шударга бусыг мэдэрсээр байна; Миний нүдээр, хүн төрөлхтөн бол эцсийн эцэст хоосон бөгөөд хүний дунд үнэ цэнтэй эрдэнэ ер үгүй. Хүний амьдралын талаар хүмүүс ямар үзэл бодолтойг Би мэдэхгүй, гэвч товчхондоо бол Миний Өөрийн үзэл бодол “хоосон” хэмээх үгээс салшгүй юм. Үүнээс болоод хүмүүс Миний талаар муугаар бодохгүй гэж Би найдаж байна, учир нь Би нэлээд шулуухан бөгөөд эелдэг байхаар хичээдэггүй. Гэвч Би Миний бодож буй зүйлд илүү их анхаарал хандуул гэж хүмүүст зөвлөмөөр байна, учир нь эцсийн эцэст Миний үг тэдэнд тустай билээ. Хүмүүс “хоосон байдлын” талаар ямар ойлголттой байдгийг Би мэдэхгүй. Тэднийг энэ ажилд жаахан хичээл чармайлт гаргана гэж Би найдаж байна. Тэд хүний амьдралыг бодитоор туулж, тэндээс үнэ цэнтэй “хүдрийн нууц судал” олж чадах эсэхээ харвал сайн сан. Би хүмүүсийн эерэг байдлыг мохоох гэж оролдож байгаа юм биш; зүгээр л Миний үгээс жаахан мэдлэг олж аваасай л гэж хүсэж байна. Би хүмүүсийн хэрэг явдлын төлөө ямагт ийш тийш яаравчилдаг, гэтэл одоо юмс ийм байхад хүртэл хүмүүс талархлын ганц ч үг хэлээгүй бөгөөд дэндүү завгүй болохоор энэ талаар мартчихсан юм шиг л байдаг. Хүн өдөржин яарч сандраад ямар үр дүнд хүрснийг Би өнөөдөр ч гэсэн бас л ойлгодоггүй. Өнөөдөр ч гэсэн хүмүүсийн зүрх сэтгэлд Миний гэх орон зай байдаггүй тул Би дахин нэгэнтээ гүн бодолд автдаг. Би “хүмүүс яагаад Намайг үнэхээр хайрлах сэтгэлгүй байдгийг” судлах ажлыг хийгээд эхэлчихсэн: Би хүнийг “хагалгааны ширээн” дээр өргөж тавиад, “зүрхийг” нь задлан шинжилж, Намайг үнэхээр хайрлах замд нь түүний зүрхэнд юу тээглэж, саад болоод байгааг харна. “Хутганы” нөлөөн дор хүмүүс нүдээ тас аниад, эхлэхийг минь хүлээнэ, учир нь энэ удаа тэд бүрмөсөн бууж өгсөн; тэдний зүрхнээс Би өөр олон хольц олсон. Тэдгээрийн дунд голчлон хүмүүсийн өөрсдийнх нь юмс байдаг. Тэд биеийнхээ гадна цөөн хэдэн юмтай байж болох ч бие доторх зүйлс нь тоймгүй олон. Хүний зүрх сэтгэл асар том агуулах сав мэт эд баялгаар, хүмүүст хэрэг болох бүх юмаар дүүрчээ. Тэр хоромд л Би хүмүүс яагаад Намайг ерөөсөө тоодоггүйг ойлгосон юм: Учир нь тэд асар их бие даасан байдалтай байна—тэдэнд Миний туслалцаа ямар хэрэгтэй юм бэ? Иймээс Би хүнийг орхин явдаг, учир нь хүмүүст Миний туслалцаа хэрэггүй; яагаад Би “ичгүүр сонжуургүй авирлаж”, тэдний зэвүүцлийг төрүүлэх ёстой юм бэ?

Яагаад гэдгийг бүү мэд, Би биеэ барьж дийлдэггүй мэт хүмүүсийн дунд үг хэлэхэд үргэлж бэлэн байсаар ирсэн. Тиймээс хүмүүс Намайг үнэ цэнгүй гэж хардаг ба сохор зоосны ч үнэгүй мэт Надад ханддаг; тэд Намайг хүндлэвээс зохих зүйл гэж үздэггүй. Тэд Намайг нандигнадаггүй, хүссэн үедээ Намайг гэртээ чирж аваачаад, дараа нь дахиад гарган хаяж, олон нийтийн өмнө Намайг “ил гаргадаг”. Хүний өөдгүй занг Би туйлаас үзэн яддаг болохоор хүн бол мөс чанаргүй гэж

шулуухан хэлдэг. Харин хүмүүс эвлэрдэггүй; тэд “сэлэм, жадаа” аваад Надтай тулаан хийж, Миний үгийг бодит байдалтай нийцдэггүй гэлцэж, Би өөрсдийг нь гутаан доромжилдог гэцгээдэг—гэвч догшин ширүүн авирласных нь хариуд Би тэднийг залхаан цээрлүүлдэггүй. Харин хүмүүсийг ятгаж, тэднийг өөрсдөөсөө ичдэг болгохын тулд Би Өөрийнхөө үнэнийг л хэрэглэдэг ба үүний дараа тэд чимээгүйхэн ухардаг. Би хүнтэй тэмцэлддэггүй, учир нь тэглээ гээд ямар ч ашиг тусгүй. Би Өөрийн үүргийг биелүүлнэ, хүн ч бас үүргээ биелүүлэх ба Миний эсрэг ажиллахгүй гэж Би найддаг. Энэ маягаар амар тайван нийцтэй явсан нь дээр бус уу? Харилцаагаа яагаад хорлоно гэж? Бид энэ олон жилийн турш эв найртай байлаа—хэн хэндээ төвөг учруулах ямар хэрэгтэй юм бэ? Тэгэх нь хэн хэний маань нэр төрд ямар ч ашиг тусгүй байх бус уу? Бидний харилцаа бол олон жилийн “хуучны барилдлага”, “хуучны танилууд”—хорсолтойгоор салах хэрэг юу билээ? Ингэх нь сайн хэрэг гэж үү? Хүмүүс нөлөөллийг нь анхаарч, өөрсдөд нь юу сайн бэ гэдгийг мэднэ гэж Би найдаж байна. Өнөөдөр хүнд хандах хандлагыг минь хүн насан туршдаа ярихад хангалттай—хүмүүс яагаад дандаа Миний сайхан сэтгэлийг таньж чаддаггүй юм бэ? Тэдэнд илэрхийлэх чадвар дутдаг учраас тэр үү? Тэдний үгсийн сан хангалтгүй гэж үү? Тэд яагаад үргэлж хэлэх үггүй байдаг юм бэ? Биеэ хэрхэн авч явдгийг минь мэддэггүй хэн байна? Хүмүүс Миний ажлыг тун сайн мэддэг—зүгээр л тэд үргэлж бусдыг далимдуулан ашиглах дуртай байдаг тул хувийн ашиг сонирхлоо хойш тавихыг огт хүсдэггүй. Нэг үг хэллэг хувийн ашиг сонирхлыг нь хөндөх л юм бол тэд давуу тал олж авах хүртлээ амрахаас татгалздаг—ингэх ямар хэрэгтэй юм бэ? Хүмүүс ямар хувь нэмэр оруулж чадах вэ гэж өрсөлдөж чаддаггүй, харин хэр ихийг олж авч чадах вэ гэж тэмцэлддэг. Тэдний байр сууринд ямар ч таашаал үгүй атал тэд түүнийгээ маш их нандигнаж, тэр ч байтугай үнэлшгүй эрдэнэ гэж үздэг тул байр суурьныхаа ашиг тусыг хаяснаас Миний гэсгээлтийг туулахыг илүүд үздэг. Хүмүүс өөрсдийгөө хэтэрхий өндрөөр боддог болохоор өөрсдийгөө хойш тавихыг хэзээ ч хүсдэггүй. Хүний талаарх Миний үнэлгээнд бага зэргийн ташаарал байж магадгүй, эсвэл Би түүнд хатуу ч биш, зөөлөн ч биш шошго зүүсэн байж магадгүй—гэхдээ товчхондоо бол, үүнийг хүмүүс анхааруулга хэмээн үзнэ гэж Би найдаж байна.

1992 оны 5 дугаар сарын 21

45-Р БҮЛЭГ

Нэгэнтээ Би гэртээ байлгах гэж чамин эд агуурс сонгосон, тэгснээр тэнд эгнэшгүй эд баялаг бий болоод гэрийг минь чимж, Би үүнээс таашаал хүртсэн юм. Гэвч Надад хандах хүний хандлагаас болоод, мөн хүмүүсийн сэдлээс болоод энэхүү ажлаа хойш тавин өөр ажил хийхээс өөр сонголт Надад байсангүй. Ажлаа

гүйцэлдүүлэхийн тулд Би хүний сэдлийг ашиглана, Би бүхий л зүйлийг чадварлагаар залан Өөртөө үйлчлүүлж, улмаар Өөрийнхөө гэрийг дүнсгэр, эзгүй байхыг нь болиулна. Би нэгэнтээ хүмүүсийн дундаас үүнийг харсан: Мах цуснаас бүтсэн бүхэн ухаангүй байдалтай байсан ба ганц ч зүйл Миний оршин тогтнолын ерөөлийг туулаагүй. Хүмүүс ерөөл дунд амьдарч байгаа атлаа хэчнээн их ерөөгдсөнөө үл мэднэ. Хэрвээ хүн төрөлхтнийг гэх Миний ерөөл өнөөг хүртэл оршин байгаагүй бол хүн төрөлхтний дундаас хэн үхэж мөхөлгүйгээр өнөөг хүртэл тэсэж чадах билээ? Хүний амьд яваа нь Миний ерөөл бөгөөд тэрээр Миний ерөөл дунд амьдардаг гэсэн үг юм, учир нь түүнд анхнаасаа юу ч байгаагүй, мөн түүнд газар дэлхий дээр, тэнгэрийн доор амьдрах хөрөнгө зөөр угаасаа байгаагүй билээ; өнөөдөр Би хүнд тусалсаар байгаа, гагцхүү үүнээс л болоод хүн Миний өмнө зогсоод, үхлээс зугтах хувьтай байна. Хүмүүс хүний оршин тогтнолын нууцыг нэгтгэн дүгнэсэн боловч энэ нь Миний ерөөл гэдгийг хэн ч, хэзээ ч ухамсарлаагүй. Үүний үр дүнд бүх хүн дэлхий ертөнц дэх шударга бус явдлыг хараан зүхэж, амьдралынхаа аз жаргалгүй байдлаас болж бүгд Миний талаар гомдоллодог. Миний ерөөл байгаагүй бол өнөөдрийг хэн үзэх байсан юм бэ? Хүмүүс тав тухтай амьдарч чаддаггүй учраас бүгдээрээ Миний талаар гомдоллодог. Хэрвээ хүний амьдрал гэгээлэг, амар амгалан байсан бол, хэрэв хүний зүрх сэтгэл рүү урьхан “хаврын сэвшээ салхи” үлээж, бүх биеэрээ хосгүй таашаал амсахад хүргэж, өчүүхэн төдий ч өвдөлт шаналалгүй байлгасан бол хүмүүсийн дундаас хэн үхэхдээ гомдоллох билээ? Хүмүүс ер нь толгой эргүүлэм дэндүү олон зальхай арга мэхтэй учраас хүний туйлын үнэнч сэтгэлийг олж авахад Надад асар хэцүү байдаг. Харин Намайг эсэргүүцэл үзүүлэх үед тэд Намайг үл тоомсорлож, Надад огт анхаарал хандуулдаггүй, учир нь Миний эсэргүүцэл тэдний сэтгэлийг хөндөж, тэднийг хөлөөсөө толгой хүртлээ босгон байгуулагдах чадваргүй болгож орхидог бөгөөд Би үргэлж тэднийг “тарчилгах” дуртай байдаг болохоор хүмүүс Миний оршин тогтнолыг үзэн яддаг. Миний үгээс болж хүмүүс дуулж, бүжиглэдэг; Миний үгээс болж чимээгүйхэн толгой гудайлгадаг; мөн Миний үгээс болж тэд асгартал уйлдаг. Миний үгэнд хүмүүс цөхөрдөг; Миний үгээс тэд амь зуух гэрлийг олж авдаг. Миний үгээс болж тэд өдөр шөнөгүй нойр нь хулжин эргэж хөрвөөдөг, мөн Миний үгээс болж тэд газар сайгүй яаран гүйлддэг. Миний үг хүмүүсийг Үхэгсдийн орон руу унагааж, дараа нь гэсгээлтэд умбуулдаг, гэвч хүмүүс өөрийн мэдэлгүй Миний ерөөлийг ч бас эдэлдэг. Хүн үүнд хүрэх боломжтой юу? Хүмүүсийн цуцалтгүй хичээл зүтгэлийн хариуд энэ бүтэх үү? Миний үгийн зохион байгуулалтаас хэн зугтаж чадах билээ? Тиймээс хүний бүтэлгүйтлээс болоод Би хүн төрөлхтөнд үгээ хайрлаж, хүний дутагдлыг үгээрээ тэтгэж, хүн төрөлхтний амьдралд эгнэшгүй эд баялаг авчирдаг.

Би хүмүүсийн үг яриа, үйлдлийг үргэлж шинждэг. Тэдний зан авир, нүүр царайны илэрхийллээс Би олон “нууцыг” олж илрүүлсэн. Хүмүүсийн бусадтай харилцах харилцаанд “нууц жор” бараг л хамгаас онцгойрч харагддаг—тиймээс

хүнтэй харилцах үедээ Би Надад хайргүй гэдгийг нь харуулдаг “хүний харилцааны нууц жорыг” олж авдаг. Би бүтэлгүйтлээс нь болоод хүнийг ямагт зэмлэдэг боловч түүний итгэлийг олж авч чаддаггүй. Хүн Надаар өөрийгөө хөнөөлгөхийг хүсдэггүй, учир нь “хүний харилцааны нууц жорд” хүн сүйрлийн гамшигт нэрвэгдэж байсныг хэзээ ч олж илрүүлээгүй—хүн золгүй явдлын үеэр л хэдхэн бүтэлгүйтэл амссан. Хүмүүс Миний үгээс болж хашхирдаг ба тэд гуйж гувшихдаа Миний хатуу сэтгэлийн талаар үргэлж гомдоллодог. Тэд бүгдээрээ л хүнийг хайрлах Миний жинхэнэ “хайрыг” хайж буй мэт байдаг—гэвч тэд Миний хатуу үгээс Миний хайрыг олж яаж чадах билээ? Үүний үр дүнд Миний үгээс болж тэд үргэлж итгэл найдвараа алддаг. Тэд Миний үгийг уншмагцаа “үхлийг” харсан мэт болдог тул айсандаа дагжин чичирдэг. Энэ нь Намайг гонсойлгодог: Үхлийн дунд амьдардаг махан биетэй хүмүүс яагаад дандаа үхлээс айдаг юм бэ? Хүн, үхэл хоёр атаат дайснууд гэж үү? Үхлийн айдас яагаад үргэлж хүмүүсийг зовоодог юм бэ? Амьдралынхаа “ер бусын” туршлагын явцад тэд үхлийг багахан л туулдаг гэж үү? Хүмүүс үг хэлээрээ яагаад Миний талаар үргэлж гомдоллодог юм бэ? Тиймээс хүний амьдралын дөрөв дэх онч мэргэн үгийг Би дүгнэн хэлье: Хүмүүс Надад өчүүхэн төдий л дуулгавартай байдаг тул Намайг дандаа үзэн яддаг. Хүн үзэн яддаг учраас Би ямагт орхин оддог. Би яагаад Өөрийгөө ийм байдалд оруулах ёстой юм бэ? Би яагаад үргэлж хүмүүсийн зэвүүцлийг төрүүлэх ёстой юм бэ? Хүмүүс Миний оршин тогтнолыг баяртайгаар хүлээн авахгүй байхад Би яагаад хүний гэрт ичгүүр сонжуургүйгээр амьдрах ёстой юм бэ? “Тээшээ” аваад хүнийг орхиж явахаас өөр сонголт Надад үгүй. Гэхдээ хүмүүс Намайг явуулж тэвчдэггүй, Намайг явуулахыг хэзээ ч хүсдэггүй. Тэд цурхиран уйлж, мэгшин, Намайг явчихлаар амьдрахын тулд түшиж тулдаг зүйлээ алдана гэхээс ихэд айдаг. Тэдний царайчилсан харцыг хараад Миний зүрх сэтгэл уярдаг. Дэлхий ертөнцийн бүх далай тэнгисийн дунд хэн Намайг хайрлаж чадах билээ? Хүн бохир усаар бүрхэгдэж, далайн хүчинд залгиулжээ. Би хүний дуулгаваргүй занг үзэн яддаг атлаа бас бүх хүн төрөлхтний золгүй явдлыг өрөвддөг—учир нь эцсийн эцэст хүн мөн л хохирогч юм. Хүнийг сул дорой, хүчин мөхөс байхад Би далайн усанд хаяж яахан чадах билээ? Би хүнийг хазайсан дээр нь түлхдэг тийм харгис нэгэн гэж үү? Миний зүрх сэтгэл тийм энэрэлгүй юм уу? Хүн төрөлхтөнд хандах хандлагаас минь үүдэн хүн энэ эрин үед Надтай хамт ордог, үүнээс болоод тэрээр эдгээр ер бусын өдөр, шөнийг Надтай хамт өнгөрүүлсэн. Өнөөдөр хүмүүс хөөрөн догдолж, Миний хайр энэрлийг асар ихээр мэдэрч, Намайг асар их урам зоригтойгоор хайрладаг, учир нь тэдний амьдрал эрч хүчтэй бөгөөд газар дэлхийн зах хязгаар руу тэнүүчилдэг үрэлгэн хүү байхаа больжээ.

Хүнтэй хамт амьдарч байх хугацаанд минь хүмүүс Надад найддаг, учир нь Би бүхий л зүйл дээр хүнд санаа тавьж, сайтар халамжилдаг, хүмүүс үргэлж Миний халуун дулаан нөмөрт амьдарч, үлээх салхи, аадар бороо, төөнөх нарны алийг ч үздэггүй; хүмүүс аз жаргалд умбан амьдарч, Намайг элбэрэлт эх шигээ үздэг. Хүмүүс бол “байгалийн гамшгийн” дайралтыг тэсэж огт чадахгүй, яагаад ч бат

зогсох чадваргүй хүлэмж дэх цэцэгс мэт билээ. Тиймээс Би тэднийг исгэрэн шуурах далайн шалгалт дунд тавьдаг ба тэд өөрийн эрхгүй тасралтгүй “дайвалздаг”. Тэдэнд сөрөн зогсох хүч үнэндээ байдаггүй—тэдний биеийн хэмжээ дэндүү дутмаг, бие нь дааНч сул дорой учраас Надад ачаа мэдрэгддэг. Тиймээс хүмүүс өөрийн мэдэлгүй Миний шалгалтад өртдөг, яагаад гэвэл тэд дэндүү хэврэг бөгөөд исгэрэх салхи, төөнөх нарыг тэсвэрлэж чаддаггүй. Энэ Миний өнөөгийн ажил бус уу? Хүмүүс Миний шалгалттай тулгарах үедээ яагаад дандаа асгартал уйлдаг юм бэ? Би тэдэнд шударга бус хандаж байна уу? Тэднийг Би зориуд хөнөөгөөд байна уу? Яагаад хүний хайр татам байдал хэзээ ч дахин сэргэхгүйгээр үхдэг юм бэ? Хүмүүс үргэлж Намайг барьж аваад тавьж явуулдаггүй; учир нь тэд хэзээ ч бие даан амьдрах чадвартай байгаагүй, үргэлж Миний гарт хөтлүүлэн, өөрсдийг нь өөр хэн нэгэн аваад явчих вий гэхээс ихэд айдаг. Тэдний бүхий л амьдралыг Би залж чиглүүлдэг бус уу? Тэд үймээнт амьдралынхаа явцад уул давж, хөндийг туулахдаа ихээхэн үймээн самуун туулсан—энэ нь Миний гараар хийгдээгүй гэж үү? Хүмүүс яагаад Миний зүрх сэтгэлийг огт ойлгож чаддаггүй вэ? Яагаад Миний сайн санааг үргэлж буруу ойлгодог юм бэ? Яагаад Миний ажил газар дэлхий дээр төвөггүй явагдаж болдоггүй юм бэ? Хүний сул дорой байдлаас болоод хүнээс ямагт зайлсхийсэн минь Намайг гуниг харуусалд автуулдаг: Яагаад Миний ажлын дараагийн алхам хүн дээр хэрэгжиж болдоггүй юм бэ? Тиймээс Би чимээгүй болж, хүнийг анхааралтай цэгнэж үздэг: Би яагаад үргэлж хүний дутагдлаас болж хязгаарлагддаг юм бэ? Яагаад Миний ажилд үргэлж саад тээг учирдаг юм бэ? Өнөөдөр Би бүрэн гүйцэд хариултыг нь хүнээс хараахан олоогүй, учир нь хүн үргэлж хэтэрхий туйлширч байдаг, хэзээ ч хэвийн байдаггүй; нэг бол тэр Намайг голдоо ортол үзэн ядаж, эсвэл Намайг дээд зэргээр хайрладаг. Хэвийн Бурхан Би Өөрөө хүний тийм тарчлааныг тэвчиж чадахгүй. Хүмүүс сэтгэцийн хувьд үргэлж хэвийн бус байдаг учраас Би харваас л хүнээс бага зэрэг эмээдэг тул түүний хөдөлгөөн бүрийг ажихдаа хэвийн бус байдлыг нь санадаг. Би хүний нууцыг санаандгүй олж илрүүлсэн юм: Хүний ард гоц ухаантан байдаг болж таарсан; үүний үр дүнд хүмүүс зөвтгөхүйц зүйл хийсэн мэт үргэлж зоримог, өөртөө итгэлтэй байдаг. Тиймээс хүмүүс үргэлж том хүний дүр эсгэж, “жаахан хүүхдийг” гоё үгээр ятгадаг. Хүний улайм цайм дүр эсгэж байгааг нь хараад хилэн минь өөрийн эрхгүй бадардаг: Хүмүүс яагаад өөрсдийгөө ингэж хайрлаж, хүндэлдэггүй юм бэ? Өөрсдийгөө яагаад мэддэггүй юм бэ? Миний үг үгүй болсон гэж үү? Миний үг хүний дайсан гэж үү? Хүмүүс Миний үгийг уншихаараа яагаад Надад улам хорсдог юм бэ? Хүмүүс яагаад үргэлж Миний үгэн дээр өөрсдийнхөө бодлыг нэмдэг юм бэ? Би хүнд хэтэрхий үндэслэлгүй хандаж байна гэж үү? Энэ талаар, Миний үгэн дотор юу агуулагддаг талаар бүх хүн сайтар бодож үзэх ёстой.

1992 оны 5 дугаар сарын 24

46-Р БҮЛЭГ

Миний үгийг оршин тогтнолынхоо үндэс болгохдоо хүмүүс хэр сайн болохыг Би мэдэхгүй. Би хүний хувь заяаны төлөө үргэлж түгшдэг атал хүмүүс үүнийг огт мэдэрдэггүй мэт санагддаг—үүний үр дүнд тэд Миний үйл хэрэгт хэзээ ч анхаарал хандуулаагүй бөгөөд хүнд хандах хандлагаас минь болоод Намайг хэзээ ч биширч байгаагүй. Тэд Миний зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд сэтгэл хөдлөлийг аль хэдийн хаясан мэт байдаг. Тийм нөхцөл байдалтай тулгараад Би дахин нэгэнтээ чимээгүй болдог. Хүмүүс эргэцүүлж, ороход Миний үг яагаад зохистой байдаггүй юм бэ? Надад бодит байдал байдаггүй ба Би хүмүүсийн эсрэг ашиглаж болох зүйлийг олохоор оролдож байгаагаас энэ нь болдог гэж үү? Яагаад хүмүүс Надад үргэлж “тусгай эмчилгээ” хийдэг юм бэ? Би тусгай тасагтаа байгаа тахир дутуу нэгэн гэж үү? Аливаа зүйлс өнөөдрийн энэ цэгт хүрчихсэн байхад яагаад хүмүүс Намайг өөрөөр харсаар байдаг юм бэ? Хүнд хандах хандлагад минь алдаа мадаг байдаг гэж уу? Өнөөдөр Би орчлон ертөнцийн дээр шинэ ажил эхлүүлсэн. Би газар дээрх хүмүүст шинэ эхлэл өгч, Миний гэрээс нүүхийг тэднээс бүгдээс нь шаардсан. Хүмүүс үргэлж өөрсдийгөө өөгшүүлэх дуртай байдаг учраас ухамсартай байж, Миний ажлыг үргэлж үймүүлэхгүй байхыг Би тэдэнд зөвлөдөг. Миний нээсэн “дэн буудалд” хүн Миний зэвүүцлийг хамгийн их төрүүлдэг, учир нь хүмүүс Надад үргэлж төвөг учруулж, Миний урмыг хугалж байдаг. Тэдний зан авир Надад ичгүүр авчирдаг бөгөөд Би толгойгоо өндөрт өргөж ер чаддаггүй байсан. Тиймээс Би тэдэнтэй тайвнаар яриад, Миний гэрээс аль болох хурдан явж, Миний хоолыг үнэ төлбөргүй идэхээ боль гэж тэднээс шаардсан. Хэрвээ үлдэхийг хүсэж байвал тэд зовлон туулж, Миний цээрлүүлэлтийг тэвчих ёстой. Тэдний бодлоор бол Би хийж байгаа зүйлийг нь огт анзаарч мэддэггүй тул Миний өмнө тэд унаж байгаа ямар ч шинж тэмдэггүйгээр бардам зогсож, тоо бөглөхийн тулд л хүний дүр эсгэж байдаг. Намайг хүмүүст шаардлага тавих үед тэд мэл гайхдаг: Маш олон жилийн туршид зан сайтай, эелдэг байсаар ирсэн Бурхан тийм хатуу цэвдэг, шударга бус үг хэлнэ гэж тэд хэзээ ч бодож байгаагүй болохоор хэлэх ч үггүй болдог. Тийм үеүдэд тэд гомдоллох ажлаа дахин эхэлсэн учраас хүмүүсийн зүрх сэтгэл дэх Надад хандах үзэн ядалт дахин нэгэнтээ ихэссэнийг Би харсан. Тэд үргэлж газрыг зүхэж, Тэнгэрийг хараадаг. Гэсэн ч, хүмүүс өөрсдийгөө асар их хайрладаг учраас тэдний үгээс Би өөрсдийгөө харааж буй юуг ч олдоггүй. Тиймээс Би хүний амьдралын утга учрыг ингэж нэгтгэн дүгнэсэн: Хүмүүс өөрсдийгөө хэтэрхий их хайрладаг болохоор тэдний бүхий л амьдрал шаналгаатай, хий хоосон байдаг бөгөөд Намайг үзэн яддагаасаа болоод тэд өөрсдийгөө сүйрүүлдэг.

Хэдийгээр хүний үгэнд Намайг гэх хэмжээлшгүй их “хайр” байдаг ч эдгээр үгийг микроскопоор шинжилж, ажиглахаар “лаборатори” руу аваачих үед дотор нь агуулагдаж байгаа бүхэн тун тодорхой илчлэгддэг. Энэ мөчид Би тэдэнд “өвчний түүхийг” нь үзүүлж, тэднийг чин сэтгэлээс нь үнэмшүүлэхээр хүмүүсийн дунд дахин

нэгэнтээ ирсэн. Хүмүүс тэдгээрийг харах үедээ царай нь уйтгар гунигт автаж, зүрх сэтгэлдээ харуусдаг бөгөөд тэр ч бүү хэл ихэд түгшдэг болохоор Намайг баярлуулахын тулд өөрсдийн муу арга замыг даруй хаяж, зөв замд буцан очихоор тэсэж яддаг. Тэдний шийдвэрийг хараад Би туйлын их баярлаж, баяр хөөрөөр бялхдаг: “Газар дээр хүнээс өөр хэн баяр хөөр, уй гашуу, зовлон бэрхшээлийг Надтай хуваалцаж чадах юм бэ? Ганцхан хүн биш гэж үү?” Гэсэн ч Намайг явах үед хүмүүс өвчний түүхээ урж, шалан дээр хаясныхаа дараа ихэмсгээр алхан оддог. Тэр цагаас хойш Би хүмүүсийн үйлдлээс Миний зүрх сэтгэлийн дагуух зүйл багыг олж харсан. Гэсэн ч Миний өмнөх тэдний шийдвэр нэлээд их хуримтлагдсан бөгөөд тэдний шийдвэрийг хараад Би зэвүүцдэг, учир нь тэдний шийдвэрт Надад таалагдах зүйл юу ч байдаггүй; хэтэрхий их хольцтой байдаг. Өөрсдийнх нь шийдвэрийг үл томсорлож буйг минь хараад хүмүүс хүйтэн хөндий болдог. Дараа нь тэд хааяахан л “өргөдөл” гаргадаг, учир нь хүний зүрх сэтгэл хэзээ ч Миний өмнө магтагдаж байгаагүй, үргэлж Надад гологддог байсан—хүмүүсийн амьдралд оюун санааны дэмжлэг байхаа больсон тул урам зориг нь алга болж, Надад цаг агаар “шатам халуун” санагдахаа больсон. Өнөөдрийн нөхцөл байдал ирснээр Би тэднийг ихэд “тарчилгадаг” болохоор тэд амьдрал, үхлийн хоорондэргэлдэх хэмжээнд насан туршдаа ихээхэн зовдог. Үүний үр дүнд тэдний нүүр царайн дахь гэрэл бүүдийж, “сэргэлэн цовоо байдлаа” алддаг, учир нь тэд бүгд “өсөж том болсон”. Гэсгээлтийн үеэр цэвэршүүлэгдэж байх үеийн хүмүүсийн өрөвдөлтэй байдлыг Би харж тэвчдэггүй—гэсэн ч хүн төрөлхтний өрөвдмөөр ялагдлыг хэн засаж залруулж чадах юм бэ? Хэн хүнийг өрөвдөлтэй амьдралаас нь аварч чадах юм бэ? Яагаад хүмүүс өөрсдийгөө зовлон шаналлын ёроолгүй ангалаас гаргаж огт чадаагүй юм бэ? Би хүмүүсийг зориуд урхиддаг уу? Хүмүүс Миний сэтгэл санааны байдлыг хэзээ ч ойлгоогүй тул тэнгэр, газар дахь бүх зүйлийн дундаас юу ч, хэзээ ч Миний зүрх сэтгэлийг ухамсарлаагүй, хэн ч Намайг үнэхээр хайрладаггүй гэж Би орчлон ертөнцөд халаглан гашууддаг. Өнөөдөр ч гэсэн, хүмүүс яагаад Намайг хайрлаж чаддаггүйг Би мэдэхгүй л байна. Тэд Надад зүрх сэтгэлээ өгч чадна, Миний төлөө хувь заяагаа золиосолж чадна, гэхдээ яагаад Надад хайраа өгч чаддаггүй юм бэ? Миний шаарддаг зүйл тэдэнд байдаггүй юм уу? Хүмүүс Надаас бусад бүх зүйлийг хайрлаж чаддаг—тэгвэл тэд яагаад Намайг хайрлаж чаддаггүй юм бэ? Яагаад тэдний хайр үргэлж нуугдмал байдаг юм бэ? Тэд өнөөг хүртэл Миний өмнө зогссон байтал Би яагаад тэдний хайрыг огт хараагүй юм бэ? Тэдэнд дутагддаг зүйл энэ гэж үү? Би хүмүүст зориуд хүндрэл учруулж байгаа гэж үү? Тэдний зүрх сэтгэлд эргэлзээ байсаар байгаа юу? Тэд буруу хүнийг хайрлахаас айж, өөрсдийгөө анагаах чадваргүй байдаг уу? Хүмүүст тоймгүй олон ойлгогдошгүй нууц байдаг бөгөөд тиймээс Би хүний өмнө үргэлж “айж, хулчийдаг”.

Өнөөдөр хаанчлалын үүд хаалга руу урагшлах цаг үед бүх хүн урагш цойлж эхэлсэн—гэхдээ тэднийг хаалганы өмнө ирэхэд Би хаалгыг хааж, хүмүүсийг гадаа

үлдээгээд, орох тасалбараа үзүүлэхийг тэднээс шаардсан. Тийм хачин үйлдэл хүмүүсийн хүлээлтээс эрс зөрдөг бөгөөд тэд бүгд мэл гайхдаг. Үргэлж нээлттэй байсаар ирсэн хаалгыг яагаад өнөөдөр гэнэт хаачхав? Хүмүүс хөлөө дэвсэлж, ийш тийш холхидог. Тэд яаж ийгээд орж чадна гэж төсөөлдөг боловч хуурамч орох тасалбаруудаа Надад өгөхөд нь Би тэр даруй гал руу шиддэг ба өөрсдийнх нь “уйгагүй хичээл чармайлт” шатаж буйг хараад тэд итгэл найдвараа алддаг. Тэд толгойгоо барин уйлж, хаанчлалын доторх үзэсгэлэнтэй сайхан дүр зургийг хардаг боловч орж чаддаггүй. Гэсэн ч өрөвдөлтэй байдлаас нь болоод Би тэднийг оруулдаггүй—хэн Миний төлөвлөгөөг хүссэнээрээ нурааж болох билээ? Ирээдүйн ерөөлүүдийг хүмүүсийн урам зоригийн хариуд өгдөг гэж үү? Хүний оршин тогтнолын утга учир нь Миний хаанчлалд хүссэнээрээ ороход оршдог гэж үү? Би маш дорд гэж үү? Хэрвээ Миний хатуу үг байгаагүй бол хүмүүс хаанчлалд аль хэдийн орчихсон байх бус уу? Тиймээс, Миний оршин тогтнол өөрсдөд нь төвөг учруулдгаас болоод хүмүүс Намайг үргэлж үзэн яддаг. Хэрвээ Би оршин байдаггүй байсан бол тэд өнөө үеийн хаанчлалын ерөөлүүдийг эдэлж чадах байсан—тэгвэл энэ зовлонг туулах ямар хэрэгтэй байх юм бэ? Иймээс хүмүүс явсан нь дээр бөгөөд өөрсдөдөө гарах гарц олохын тулд өнөө үед аливаа зүйлс сайн явагдаж байгааг ашиглах ёстой; тэд залуу насандаа зарим нэг ур чадварт суралцахын тулд өнөө үеийг ашиглах ёстой, эс бөгөөс ирээдүйд энэ нь хэтэрхий оройтсон байх болно гэж Би хүмүүст хэлдэг. Миний гэрт хэн ч, хэзээ ч ерөөл хүртээгүй. Би хүмүүст, даруйхан яв, “ядуу зүдүү” амьдралтай бүү зууралд гэж хэлдэг; хожим харамсахад хэтэрхий оройтсон байх болно. Өөрсдөдөө хэтэрхий хатуу бүү ханд; өөртөө төвөг удах ямар хэрэгтэй юм бэ? Гэхдээ Би бас хүмүүст, ерөөл хүртэж чадахгүй байх үедээ хэн ч Надад гомдоллож болохгүй гэж хэлсэн. Өөрийн үгийг хүмүүст дэмий үрэх цаг зав Надад байхгүй. Энэ нь хүмүүсийн оюун ухаанд үлдээд, тэд үүнийг мартахгүй гэж Би найдаж байна—эдгээр үг бол Миний өгдөг таагүй үнэн юм. Би хүнд итгэх итгэлээ аль хэдийн алдсан, хүмүүст найдах найдвараа аль хэдийн алдсан, учир нь тэд хүсэл эрмэлзэлгүй байдаг бөгөөд Бурханыг хайрладаг зүрх сэтгэлийг Надад хэзээ ч өгч чадаагүй, харин оронд нь Надад үргэлж өөрсдийнхөө сэдлийг өгдөг. Би хүнд ихийг хэлсэн бөгөөд хүмүүс өнөөдөр Миний зөвлөгөөг үл ойшоосоор байдаг тул хожим нь Миний зүрх сэтгэлийг буруугаар ойлгохоос сэргийлэхийн тулд Би тэдэнд Өөрийн үзэл бодлыг хэлдэг; айсуй цаг үед амьдрах уу, эсвэл үхэх үү гэдэг нь тэдний хэрэг; Би үүнийг хянадаггүй. Тэд амьд үлдэх замаа олно гэж Би найдаж байна. Энэ тухайд бол Би хүчин мөхөс. Хүн Намайг үнэхээр хайрладаггүй тул бид зүгээр л хагацсан; хожим нь бидний хоорондх ямар ч үг байхаа больж, цаашид бидэнд ярилцах зүйл байхаа больж, бид нэг нэгэндээ саад болохгүй, тус тусынхаа замаар явна, хүмүүс Намайг хайж ирэх ёсгүй бөгөөд Би дахин хэзээ ч хүний “тусламжийг” гуйхгүй. Энэ нь бидний хоорондох зүйл бөгөөд ирээдүйд ямар нэг асуудал гарахаас сэргийлэхийн тулд бид бүгд тодорхой ярилцсан. Ингэх нь юмыг илүү амар хялбар болгодог бус уу? Бид дор бүрнээ тус тусын замаар явж, бие

биетэйгээ ямар ч хамаагүй байдаг—үүнд буруу зүйл юу байгаа юм бэ? Хүмүүс үүнийг бодолцож үзнэ гэж Би найдаж байна.

1992 оны 5 дугаар сарын 28

47-Р БҮЛЭГ

Хүмүүсийн амийг төлөвшүүлж, хүмүүстэй хамт нийтлэг хүсэл эрмэлзэлтэй байснаар үр дүнд хүрэхийн тулд Би хүмүүсийг үргэлж хүлээн зөвшөөрч, Миний үгээс хангалт, шим тэжээл олж аваад, Миний бүх эд баялгийг хүртэх боломж олгосон. Би хүмүүсийг хэзээ ч ичээж байгаагүй атал хүмүүс Миний мэдрэмжийг хэзээ ч бодолцон үзэж байгаагүй. Учир нь хүмүүс хатуу сэтгэлтэй бөгөөд Надаас бусад зүйлсийг “үзэн яддаг”. Дутагдлаас нь үүдэн Би тэднийг ихэд өрөвддөг; тиймээс дэлхий ертөнц дээр амьдрах хугацаандаа газар дэлхийн бүх эд баялгийг ханатлаа эдлэг гэсэндээ Би хүмүүст арай илүү хичээл чармайлт гаргасан билээ. Би хүмүүст шударга бусаар ханддаггүй бөгөөд Намайг олон жил дагасныг нь бодолцон үзээд тэднийг гэх зүрх сэтгэлээ зөөлрүүлсэн. Би Өөрийнхөө ажлыг энэ хүмүүс дээр хийж тэвчих аргагүй мэт санагддаг. Тиймээс Намайг өөр шигээ хайрладаг хэрзгэр туранхай энэ хүмүүсийг хараад Миний зүрх сэтгэлд үгээр хэлэхийн аргагүй шаналал мэдрэгддэг. Гэхдээ хэн үүнээс болоод тогтсон журмыг зөрчиж болох билээ? Хэн үүнээс болж өөрийгөө үймүүлэх билээ? Гэсэн ч Би хүмүүст бүрэн дүүрэн эдлүүлэх гэж Өөрийн бүх эд баялгийг өгсөн бөгөөд энэ явдал дээр хүмүүст зохисгүй хандаагүй юм. Тиймээс хүмүүс Миний энэрэнгүй, өгөөмөр төрхийг харсаар байдаг. Би үргэлж тэвчээртэй байж, үргэлж хүлээсээр ирсэн. Хүмүүс хангалттай их таашаал авч, залхаад ирэхийн цагт Би тэдний хүсэлтийг “хангаж” эхлэн, хоосон амьдралаас нь зугтаалгаж, хүмүүстэй дахин хэзээ ч харьцахгүй болгоно. Газар дэлхий дээр Би далайн ус ашиглан хүмүүсийг залгиж, тэднийг өлсгөлөн гачаалаар хянаж, шавжийн тахлаар сүрдүүлж, тэднийг “услахын” тулд аадар бороо ашигласан ч тэд амьдралын хоосон байдлыг хэзээ ч мэдрээгүй. Хүмүүс одоо ч гэсэн газар дээр амьдрахын утга учрыг ойлгодоггүй. Миний өмнө амьдрах нь хүний амьдралын хамгийн гүн гүнзгий утга учир биш гэж үү? Миний дотор байх нь гамшгийн аюулаас зугтахад туслахгүй гэж үү? Газар дэлхий дээр хэчнээн олон бие махбод бие даасан эрх чөлөөтэй байдалд амьдарч байсан бэ? Махан биеийн амьдралын хоосон байдлаас хэн зугтсан бэ? Гэхдээ хэн үүнийг танин мэдэж чадах вэ? Хүн төрөлхтнийг бүтээсэн цагаас минь хойш нэг ч хүн газар дээр хамгийн их утга учиртай амьдралаар амьдарч чадаагүй, иймээс хүн төрөлхтөн амьдралаа туйлын утга учиргүй дэмий өнгөрүүлсэн. Гэхдээ хэн ч ийм төвөгтэй байдлаас салахыг хүсдэггүй, хэн ч ийм хоосон, залхмаар амьдралаас зайлсхийхийг хүсдэггүй. Хүмүүсийн туршлагаар бол, махан биед амьдардаг хүмүүс Надаас авах

таашаалыг ашигладаг байсан хэдий ч тэдний нэг нь ч хүний ертөнцийн ёс заншлаас салаагүй билээ. Үүний оронд тэд үргэлж жам ёсонд захирагдаж, өөрсдийгөө хуурсаар ирсэн.

Намайг хүн төрөлхтний оршин тогтнолыг бүрмөсөн төгсгөмөгц газар дэлхийн “хавчлагыг” тэсвэрлэх ганц ч хүн үлдэхгүй; тэр үед л Миний агуу ажлыг бүрэн дүүрэн гүйцэлдсэн гэж хэлэх боломжтой болно. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болох үедээ Миний гүйцэлдүүлэхийг хүсдэг ажил бол махан биед амьдрахын хоосон байдлыг хүмүүст ойлгуулах явдал бөгөөд энэ боломжийг ашиглан махан биеийг устгана. Тэр үеэс эхлээд газар дээр нэг ч хүн оршин байхаа больж, газар дэлхийн хоосон байдлын тухай хэн ч хэзээ ч уйлахаа больж, махан биеийн бэрхшээл хүндрэлийн талаар хэн ч, хэзээ ч ярихаа больж, Намайг шударга бус гэж хэн ч гомдоллохоо больж, бүх хүн болон бүх зүйл амралтад орно. Дараа нь хүмүүс өөрсдөдөө тохирсон хүрэх газрыг олсон байх тул ийш тийш яаравчлан, байнга завгүй байхаа болино, мөн газар дэлхийн энд, тэндээс юм хайхаа ч болино. Тэр үед бүх хүний нүүр царайд инээмсэглэл тодорно. Тэгээд Би хүмүүсээс юу ч шаардахаа больж, цаашид ч тэдэнтэй маргахаа болино; бидний хооронд энхийн гэрээ гэж байхаа болино. Би газар дэлхий дээр оршиж, хүмүүс газар дээр амьдардаг; Би тэдэнтэй хамт амьдарч, оршин суудаг. Тэд бүгд Миний дэргэд байхын баяр баяслыг мэдэрдэг тул ямар ч шалтгаангүйгээр явахыг хүсдэггүй бөгөөд харин ч Намайг арай удаан хамт байлгахыг илүүд үзнэ. Би огт туслалгүйгээр газар дэлхийн хоосролыг харж яахан тэвчих билээ? Би газар дэлхийнх биш; тэвчээрийн ачаар л Би өөрийгөө хүчлэн байж өнөөдрийг хүртэл энд үлдсэн. Хүмүүс эцэс төгсгөлгүй гуйгаагүй сэн бол Би аль эрт явчих байлаа. Өнөө үед хүмүүс өөрсдийгөө харж хандаж чаддаг ба тэдэнд Миний тус дэм хэрэггүй, учир нь тэд төлөвшиж, Надаар тэжээлгэх шаардлагагүй болсон. Тиймээс Би хүмүүстэй хамт “ялалтын баяр” тэмдэглэхээр төлөвлөж байгаа бөгөөд дараа нь хүмүүсийг мэдэхгүй байх вий гэсэндээ Би тэдэнтэй салах ёс гүйцэтгэнэ. Мэдээж, бидний хооронд ямар ч хорсол байхгүй учраас муудалцан салах нь сайн зүйл биш. Тиймээс бидний барилдлага мөнхөд үргэлжилнэ. Бид тус тусын замаа хөөсний дараа хүмүүс Миний “өвийг” үргэлжлүүлж, амьдралынхаа туршид Миний заасан сургаалыг мартахгүй байж чадна гэж Би найдаж байна. Тэд Миний нэрд гутамшиг авчрах зүйл хийхгүй, харин Миний үгэнд хайхрамжтай хандана гэж Би найдаж байна. Намайг явсны дараа хүмүүс Намайг хангалуун байлгахын тулд хамаг чадлаараа хичээж чадна гэж Би найдаж байна; тэд Миний үгийг амьдралынхаа суурь болгон ашиглана, мөн Миний найдварыг хөсөрдүүлэхгүй гэж Би найдаж байна, учир нь Миний зүрх сэтгэл үргэлж хүмүүсийн төлөө зовниж, Би үргэлж тэдэнд сэтгэл татагдсаар ирсэн билээ. Нэгэнтээ Би хүмүүстэй хамт цугларч, тэнгэрт байдагтай адил ерөөлийг газар дээр эдэлсэн. Би хүмүүстэй хамт амьдарч, тэдэнтэй хамт оршин суусан; хүмүүс Намайг үргэлж хайрлаж, Би тэднийг үргэлж хайрласан. Бид бие биетэйгээ ойр дотно байсан. Хүмүүстэй хамт байсан цагаа

эргээд бодох үедээ Би инээд хөөр, баяр баяслаар дүүрэн өдрүүдээ санадаг, тэгэхэд бас хэрүүл маргаан ч байсан. Гэсэн ч бидний хайр үүн дээр л тогтсон ба бидний хоорондох харилцаа хэзээ ч тасраагүй. Олон жил харилцахдаа хүмүүс Надад гүн гүнзгий сэтгэгдэл үлдээсэн бөгөөд Би ч бас хүмүүст эдэлж болох асар олон зүйлийг өгсөн, үүний төлөө тэд үргэлж хоёр дахин их талархсаар ирсэн билээ. Одоо бидний цуглаан хэзээ ч урьдынхтай адил байхгүй; бидний салж хагацах энэ мөчөөс хэн зугтаж чадах билээ? Хүмүүс Намайг гүн гүнзгий хайрласан, Би ч тэднийг хязгааргүй хайрласан—гэхдээ одоо яалтай ч билээ дээ? Тэнгэрлэг Эцэгийн шаардлагыг хэн зөрчиж зүрхлэх билээ? Би оршин суудаг газартаа буцан очоод, тэнд Өөрийнхөө ажлын өөр нэг хэсгийг гүйцээнэ. Магадгүй бидэнд дахин учрах боломж гарах байх. Хүмүүс хэт их гуниглалгүй, газар дэлхий дээр Намайг сэтгэл хангалуун байлгана гэж Би найдаж байна; тэнгэр дэх Миний Сүнс тэдэнд нигүүлслээ үргэлж хайрлана.

Бүтээлийн цаг үед Би, эцсийн өдрүүдэд Өөртэйгөө нэг санаатай бүлэг хүмүүсийг бий болгоно гэж зөгнөсөн билээ. Эцсийн өдрүүдэд газар дэлхий дээр жишиг тогтоосныхоо дараа оршин суудаг газар луугаа буцна гэж Би зөгнөсөн юм. Бүх хүн Намайг сэтгэл хангалуун болгомогцоо өөрсдөөс нь Миний шаардсан зүйлийг биелүүлсэн байх бөгөөд Би тэднээс ямар нэг зүйл хий гэж шаардахаа болино. Харин хүн бид хоёр хуучны өдөр хоногуудынхаа тухай түүхийг ярилцаад, дараа нь салан явцгаах болно. Би энэ ажлыг эхлүүлсэн ба хүмүүс Намайг буруугаар ойлгож, Миний санаа зорилгыг харгис, цэвдэг гэж бодох вий гэсэндээ тэдний сэтгэл санааг бэлдэж, тэдэнд Өөрийн санаа зорилгыг ойлгуулсан. Хүмүүс Надад хайртай мөртөө Намайг тохиромжтой амралтын газарт байлгахаас татгалздаг гэж үү? Тэд Миний төлөө тэнгэрлэг Эцэгээс гуйхыг хүсдэггүй гэж үү? Хүмүүс Надтай хамт өрөвдсөн нулимс урсгаагүй гэж үү? Тэд Эцэг, Хүү Биднийг эрт эргэн нэгдэхэд туслаагүй гэж үү? Тэгвэл тэд одоо яагаад хүсэхгүй байна вэ? Газар дэлхий дээрх Миний үйлчлэл биелсэн бөгөөд хүмүүсээс салж хагацсаныхаа дараа ч Би тэдэнд тусалсаар байх болно; энэ нь сайн хэрэг биш үү? Ажлаа илүү үр дүнтэй, харилцан ашиг тустай байлгахын тулд хэчнээн шаналгаатай байсан ч бид салж хагацах ёстой. Бидний нулимс чимээгүйхэн урсана; Би хүмүүсийг зэмлэхээ болино. Урьд нь Би хүмүүст олон зүйл хэлсэн ба бүгд тэдний зүрх сэтгэлийг шархлуулан, тэднийг гуниглуулж, уйлуулсан. Үүнийхээ төлөө Би одоо хүмүүсээс хүлцэл өчиж, уучлал гуйж байна. Намайг үзэн ядахгүй байхыг Би гуйж байна, учир нь энэ бүхэн тэдний сайн сайхны төлөө байдаг. Тиймээс, хүмүүс Миний сэтгэлийг ойлгоно гэж Би найдаж байна. Урьдын цагт бид маргалдаж байсан ч эргээд харахад бидний аль алинд ашиг тустай байжээ. Эдгээр маргаанаас болоод Бурхан болон хүмүүс нөхөрлөлийн гүүр барьжээ. Энэ нь бидний хамтын хичээл чармайлтын үр дүн биш гэж үү? Бид бүгд үүнийг таашаах ёстой. Би хүмүүсээс Миний урьдын “алдааг” уучлахыг хүсэж байна. Тэдний гэм буруу ч бас мартагдах болно. Тэд ирээдүйд Надад хайраар хандаж чадаж байгаа цагт тэнгэр дэх Миний Сүнс тайвширна. Энэ

тухайд хүмүүс ямар шийдвэртэй байгааг—мөн хүмүүс Миний сүүлчийн хүсэлтийг биелүүлэхэд бэлэн байх эсэхийг Би мэдэхгүй. Би тэднээс өөр юу ч хүсдэггүй, харин Намайг хайрлаач гэж л хүсдэг. Тэр л хангалттай. Үүнийг биелүүлж чадах уу? Бидний дунд болсон бүх таагүй зүйл өнгөрсөнд үлдэг; бидний хооронд үргэлж хайр байг. Би хүмүүст маш их хайр өгсөн бөгөөд тэд Намайг хайрлахын тулд маш их төлөөс төлсөн юм. Тиймээс, бидний хоорондох хольцгүй, цэвэр ариун хайрыг хүмүүс нандигнаж, бидний хайр хүний ертөнц даяар түгж, үүрд мөнхөд өвлөгдөнө гэж Би найдаж байна. Дахин уулзахдаа бид хайраар холбогдсон хэвээр байж, бидний хайр мөнхөд үргэлжилж, бүх хүн үүнийг магтаж, түгээж байх болтугай. Энэ нь Намайг сэтгэл хангалуун болгож, Би хүмүүст инээмсэглэсэн царайгаа харуулах болно. Хүмүүс Миний захиасыг санаж явна гэж Би найдаж байна.

1992 оны 6 дугаар сарын 1

ХАВСРАЛТ

“БҮХ ОРЧЛОН ЕРТӨНЦӨД ХАНДСАН БУРХАНЫ АЙЛДВАРУУД”-ЫН НУУЦЫН ТУХАЙ ТАЙЛБАР

1-Р БҮЛЭГ

Бурханы хэлсэнчлэн “Хэн ч Миний үгийн үндсийг ухаарч чадахгүй, тэдгээрийг хэлж буй зорилгыг минь ч мэдэж чадахгүй”, хэрвээ Бурханы Сүнсний удирдамж байгаагүй бол, Түүний айлдварууд гарч ирээгүй бол бүх хүн Түүний гэсгээлт дор мөхөх байсан. Бурхан бүх хүнийг туршихад яагаад ийм удаан хугацаа зарцуулсан бэ? Таван сарын урт удаан хугацааг? Энэ нь яг нарийндаа бидний нөхөрлөлийн гол цэг, мөн түүнчлэн Бурханы мэргэн ухааны төв цэг юм. Бид дараах байдлаар үзэж болно: Хүнийг шалгалтад оруулах энэ хугацаа байгаагүй бол, Бурхан завхарсан хүн төрөлхтнийг хүчтэй цохиж, хөнөөж, цавчаагүй бол, мөн чуулганыг барьж байгуулах нь өнөөдрийг хүртэл үргэлжилсэн бол үр дүн нь ямар байх байсан бэ? Иймээс хамгийн эхний өгүүлбэрт Бурхан гол асуудалдаа шууд орж, энэ хэдэн сарын ажлын хүссэн үр нөлөөг шуудхан заан үзүүлсэн—Тэр үнэхээр голыг нь олж хэлсэн юм! Энэ хэдэн сарын хугацаан дахь Бурханы үйл хэргийн мэргэн ухааныг энэ нь хангалттай харуулдаг: Энэ нь хүмүүсийг, шалгалтаар дамжуулан захирагдаж, чин сэтгэлээсээ өөрсдийгөө зарлагадаж сурч, мөн түүнчлэн шаналгаат цэвэршүүлэлтээр дамжуулан Бурханыг илүү сайн мэдэж авах боломжтой болгосон. Хүмүүс цөхрөх тусмаа, өөрсдийгөө илүү сайн мэдэж авдаг. Үнэнийг хэлэхэд, тэд зовлонгоор дүүрэн цэвэршүүлэлттэй тулгарах тусмаа, өөрсдийнхөө завхралыг төдий чинээ их мэдэж авч, Бурханы үйлчлэл үзүүлэгч байх ч үнэ цэнгүй бөгөөд үйлчлэл үзүүлнэ гэдэг Түүгээр өргөгдөж байгаа хэрэг гэдгийг ойлгохдоо тулдаг. Иймээс, энэ үр дүнд хүрсний дараа, хүн өөрийнхөө хэсэг бүрийг ашиглаад дуусах үед Бурхан юу ч нуулгүйгээр, өршөөлийн дуу хоолойгоор шууд айлддаг. Энэ хэдэн сарын дараа Бурханы ажиллах арга барил өнөөдрийг эхлэлийн цэгээ болгосон гэдгийг бэлхнээ харж болно; Тэр үүнийг хүн бүрд илэрхий болгосон. Учир нь, Бурхан урьд нь “Бурханы ардууд гэж нэрлэгдэх эрхийг олж авах нь амаргүй” гэж үргэлж хэлдэг байсан тул үйлчлэл үзүүлэгч гэгддэг хүмүүст эдгээр үгийг хэлсэн нь Бурхан бол ямар ч эргэлзээгүй итгэмжит юм гэдгийг хангалттай харуулдаг. Бурханы хэлдэг юм бүхэн янз бүрийн түвшинд биелэх бөгөөд дэмий хоосон яриа яавч биш билээ.

Бүх хүн самуурч сатаарахдаа тултал гаслан, уй гашуугаар дүүрсэн үед Бурханы иймэрхүү үг байндаа тусаж, арга мухардсан бүх хүнийг сэргээдэг. Хүмүүсийн оюун санаанаас цаашдын эргэлзээг нь арилгахын тулд Бурхан: “тэднийг Миний ардууд гэдэг хэдий ч энэ цол нь Миний ‘хөвгүүд’ гэж дуудуулахаас огтхон ч дорд биш юм” хэмээн нэмж хэлсэн билээ. Зөвхөн Бурхан л Өөрийн эрх мэдлийг хамгаалж чадна гэдгийг энэ нь хангалттай харуулдаг ба хүмүүс үүнийг уншмагцаа энэ нь ажиллах арга зам ер биш, харин бодит баримт гэдэгт бүр ч баттай итгэнэ. Цаашлаад ингэснээр хүмүүсийн үзэгдэл бүрхэг биш хэвээр үлдэж, Түүний шинэ хандлагаар хүн бүрийн ялгамж чанар тодорхой болдог. Энэ нь Бурханы мэргэн ухааныг харуулахад хангалттай бөгөөд Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийг нэвт харж чадна

гэдгийг хүмүүст илүү сайн мэдүүлдэг; бодол, үйлдлээрээ хүмүүс нь Бурханаар удирдуулж байдаг утсан хүүхэлдэйтэй адил, энэ бол гарцаагүй, маргаангүй юм.

Эхлэлийг нь дахиад харвал, Өөрийнх нь ажлын эхний алхам буюу “чуулганыг ариусгах” ажил аль хэдийн дууссан гэдгийг Бурхан эхнээсээ шууд заан үзүүлсэн. “Нөхцөл байдал урьдынх шигээ биш болж, Миний ажил шинэ эхлэлд орсон.” Энэ өгүүлбэрээс, Бурханы ажил шинэ эхлэлийн цэгт орсон гэдгийг харж болох бөгөөд үүний дараа Тэрээр Өөрийн ажлын дараагийн алхмын зураг төслийг нэн даруй бидэнд заан харуулсан—чуулганыг байгуулж дуусмагц Хаанчлалын эрин үеийн амьдрал эхэлнэ, “учир нь энэ нь одоо чуулганыг байгуулах эрин үе байхаа больсон, харин ч энэ нь хаанчлал амжилттай байгуулагдах эрин юм.” Түүнчлэн, хүмүүсийг газар дэлхий дээр байсаар байгаа цагт тэдний цуглааныг чуулган гэж нэрлэсээр байх бөгөөд ийм маягаар, хүн бүрийн төсөөлсөн бодит бус “хаанчлал” биеллээ олохоос зайлсхийнэ хэмээн Тэр хэлсэн. Дараа нь үзэгдлийн асуудлын талаар нөхөрлөе.

Одоо үе хаанчлалыг байгуулах эрин, чуулганы байгуулалтын төгсгөл хэдий ч яагаад бүх цуглааныг чуулган гэж нэрлэсээр байгаа юм бэ? Урьд нь, чуулган бол хаанчлалын анхдагч гэж хэлдэг байсан ба чуулгангүйгээр хаанчлалын тухай ямар ч яриа байж болохгүй. Хаанчлалын эрин үеийн эхлэл бол махбод дахь Бурханы үйлчлэлийн эхлэл бөгөөд Хаанчлалын эрин үеийг бие махбодтой болсон Бурхан авчирдаг. Түүний авчирдаг зүйл нь хаанчлал албан ёсоор буун ирэх явдал биш, харин Хаанчлалын эрин үе юм. Үүнийг төсөөлөхөд хэцүү биш; Бурханы ардууд гэдгээр Би хаанчлалын ардуудыг биш, харин Хаанчлалын эрин үеийн хүмүүсийг хэлж байгаа. Тиймээс газар дээрх цуглааныг чуулган хэмээн нэрлэсээр байх нь зүйтэй. Урьд нь Тэрээр Өөрийн хэвийн хүн чанар дотор үйлдсэн хэр нь Бурхан Өөрөө гэж хараахан гэрчлэгдээгүй тул хүмүүсийн дунд Хаанчлалын эрин үе хараахан эхлээгүй; өөрөөр хэлбэл, Миний хэлсэнчлэн Миний Сүнс Миний махбод болсон биед хараахан албан ёсоор ажиллаж эхлээгүй байсан. Одоо Бурхан Өөрөө гэрчлэгдсэн болохоор хаанчлал хүмүүсийн дунд биеллээ олдог. Би бурханлаг чанар дотроо ажиллаж эхэлнэ гэдгийг энэ нь илтгэдэг тул бурханлаг чанарааараа Миний хэлдэг үг, хийдэг үйл хэргийг таашаан эдэлж чаддаг хүмүүс Хаанчлалын эрин үеийн Миний ардууд гэгдэх болно. Үүнээс “Бурханы ардууд” бий болсон юм. Энэ үе шатанд үндсэндээ Миний бурханлаг чанар ажиллаж, үг хэлдэг. Хүн хөндлөнгөөс оролцож чадахгүй, Миний төлөвлөгөөг үймүүлж ч чадахгүй. Бурхан үгээрээ тодорхой үе шатанд хүрмэгц Түүний нэр гэрчлэгдэж, энэ үеэс хүн төрөлхтнийг шалгах шалгалтууд нь эхэлнэ. Энэ бол Бурханы ажил дахь мэргэн ухааны оргил юм. Энэ нь дараагийн алхмын эхлэл, мөн түүнчлэн сүүлчийн алхмын төгсгөлийн төлөөх бат суурийг тавьж, уг үндсийг нь суулгадаг. Энэ бол ямар ч хүний таамаглаж чадахааргүй зүйл юм; энэ бол шүүлтийн эриний эхний болон хоёр дахь хэсгийн уулзах цэг билээ. Хүнийг цэвэршүүлсэн хэдэн сар байгаагүй бол Миний бурханлаг чанар ажиллах аргагүй байх байлаа. Цэвэршүүлэлтийн тэр хэдэн сар

Миний ажлын дараагийн алхмын замыг нээсэн юм. Энэ хэдэн сарын ажил зогссон нь ажлын дараагийн үе шат илүү гүн гүнзгий байна гэдгийн тэмдэг билээ. Хэрвээ хүн Бурханы үгийг үнэхээр ойлгодог бол Тэрээр Өөрийн ажлын дараагийн алхмыг эхлүүлэхийн тулд энэ хэдэн сарын хугацааг ашиглаж, улмаар илүү сайн үр дүнд хүрч байгаа гэдгийг ухаарч чадна. Хүн чанарын минь бартаа Миний ажлын дараагийн алхамд саад учруулсан, тиймээс энэ хэдэн сарын зовлонт цэвэршүүлэлтээр хоёр тал хоёулаа босгон байгуулагдаж, бодит үр ашиг хүртсэн. Үүний үр дүнд, хүн одоо л өөрийг нь нэрлэх арга замыг минь нандигнаж эхэлдэг. Тиймээс Бурханыг бийрээ эргэлдүүлэн, хүмүүсийг цаашид “үйлчлэл үзүүлэгч” гэж нэрлэхгүй, харин “Бурханы ардууд” гэх болно хэмээн хэлэх үед тэд бүгд баяр хөөрөөр бялхсан. Энэ нь хүний эмзэг газар байв. Хүний яг энэ амин цэгийг барьж аваад Бурхан тийнхүү хэлсэн юм.

Бүх хүнийг улам үнэмшүүлж, үнэн сэтгэлийн итгэлийг нь олж авахын тулд, мөн зарим хүний үнэнч сэтгэлд хольц байдаг гэх баримтыг зааж үзүүлэхийн тулд Бурхан хүний янз бүрийн муухай байдалд анхаарал хандуулах нэмэлт арга хэмжээ авч, улмаар Өөрийн энэ үгийг биелүүлсэн: “Хэчнээн хүн Намайг чин сэтгэлээсээ хайрладаг вэ? Өөрсдийнхөө ирээдүйг бодолцон үзсэний улмаас үйлддэггүй хэн байна вэ? Эдгээр шалгалтын туршид хэн хэзээ ч гомдоллоогүй вэ?” Иймэрхүү үгээс хүмүүс өөрсдийн дуулгаваргүй, үнэнч бус байдлыг болон ачлал элбэрэл дутмаг байгаагаа танин мэдэж, улмаар Бурханыг эрж хайдаг бүх хүнийг Бурханы өршөөл, хайр энэрэл цаг ямагт дагаж байдгийг харж чадна. Үүнийг дараах үгээс харж болно: “Зарим хүн ухарч няцахын ирмэг дээр байх үед, мөн Намайг ярианы өнгөө өөрчлөөсэй гэж найддаг бүх хүн итгэл найдвараа алдах үед Би авралын дуу чимээ гаргаж, Намайг чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүсийг Өөрийн хаанчлалд, Өөрийн сэнтийн өмнө буцаан авчирдаг.” Энд буй “Намайг чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүс” гэсэн хэллэг болон “Хэчнээн хүн Намайг чин сэтгэлээсээ хайрладаг вэ?” хэмээх асуулт өөр хоорондоо зөрчилддөггүй. Энэ хам сэдэв дэх “чин сэтгэл”-д хольц байдаг гэдгийг тэдгээр нь харуулдаг. Бурхан юу ч мэддэггүй юм биш; харин Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг харж чаддаг учраас л “чин сэтгэл” гэх мэт үгийг ашигладаг нь завхарсан хүн төрөлхтөн рүү чиглэсэн егөөдөл бөгөөд Бурханд өртэйг нь хүн бүрд гүн гүнзгий мэдрүүлэн, өөрсдийгөө илүү их буруутгахад тэднийг хүргэж, түүнчлэн өөрсдийнх нь зүрх сэтгэл дэх гомдол дургүйцэл бүхэлдээ Сатанаас ирдэг гэх баримтыг ухааруулахын төлөө байдаг. “Үнэнч байдал” гэх зэрэг үгийг хараад хүн бүр гайхаж, “Би олон удаа Тэнгэр, газрыг хараан зүхэж, олон удаа орхин явахыг хүссэн боловч Бурханы захиргааны зарлигаас айсандаа асуудлыг арай ядан аргацааж, олныг даган явж, Бурхан надтай харьцахыг хүлээн, юмс үнэхээр ямар ч найдлагагүй болж таарвал аажмаар ухрах цаг надад хангалттай бий гэж бодож байсан. Гэтэл одоо Бурхан биднийг Өөрийн үнэнч ардууд гэж нэрлэж байна. Бурхан үнэхээр хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг харж чаддаг Бурхан мөн гэж үү?” хэмээн дотроо боддог. Ийм төрлийн үл ойлголцлоос зайлсхийхийн тулд Бурхан бүр эцэст нь л янз бүрийн хүмүүсийн сэтгэл санааны

байдалд анхаарал хандуулан, дотроо эргэлзэж байсан хэр нь гаднаа баяр хөөр илэрхийлж байсан байдлаас зүрх сэтгэл, үг хэл болон нүдээрээ үнэмшсэн байдалд хүн бүрийг оруулсан. Ийм маягаар Бурханы үгийн талаарх хүний сэтгэгдэл гүнзгийрэн, үүний үр дүнд хүн Бурханаас илүү их айж, илүү их хүндлэх болж, түүнчлэн Бурханы талаар илүү дээр ойлголттой болсон юм. Эцэст нь хүний санаа зовнилыг намжаахын тулд Бурхан: “Гэхдээ өнгөрсөн үе бол өнгөрсөн үе, одоо үе хэдийн ирчихсэн болохоор цаашид өнгөрснийг үгүйлэн халаглах юм уу ирээдүйн тухай бодох хэрэггүй” хэмээн хэлсэн билээ. Ийм төрлийн хурц, эв зохицолтой атлаа товч тодорхой ярих байдал нь бүр ч их үр нөлөөтэй бөгөөд Түүний үгийг уншдаг бүх хүнийг, урьдын цөхрөл дундаасаа гэрлийг дахин нэгэнтээ харж, Бурханы мэргэн ухаан болон үйл хэргийг харж, “Бурханы ардууд” хэмээх нэршлийг олж авч, өөрсдийн зүрх сэтгэлд буй эргэлзээг арилгаад, дараа нь хувьсамтгай сэтгэл санааны байдлаасаа өөрсдийгөө мэдэж авахад хүргэдэг. Эдгээр нөхцөл байдал нь ээлжлэн солигдоод, уй гашуу, гаслан зовлон болон аз жаргал, баяр хөөрийг бий болгодог. Энэхүү бүлэгт Бурхан хүмүүсийн дүр төрхийн нарийн ширийнийг маш бодитоор, тод томруун дүрсэлсэн болохоор энэ нь төгс төгөлдрийн туйлд хүрсэн. Энэ нь үнэхээр хүний хүрч чадахгүй зүйл, мөн хүний зүрх сэтгэлийн гүн дэх нууцуудыг үнэхээр ил болгодог зүйл юм. Энэ нь хүний хийж чадах зүйл мөн гэж үү?

Үүний яг дараагаар, бүр ч илүү чухал нь доор буй хэсэг бөгөөд энэ нь Бурханы захиргааны зарлигийг хүнд шууд илчилдэг, мөн түүнчлэн хамгийн чухал хэсэг юм: “Хүн мөртөө бодит байдлын эсрэг явж, аливааг Миний удирдамжийн дагуу хийдэггүй хэн ч бай сайнаар дуусахгүй, харин өөрсдөдөө л төвөг удна. Орчлон ертөнц дээр тохиолддог бүх зүйлээс эцсийн шийдвэрийг нь Би гаргадаггүй юу ч үгүй.” Энэ нь Бурханы захиргааны зарлиг биш гэж үү? Энэхүү захиргааны зарлигийг зөрчдөг хүмүүсийн жишээ тоймгүй олон гэдгийг энэ нь хангалттай харуулдаг. Дээрхэд үндэслэвэл, өөрсдийн хувь заяаг бодохгүй бай гэж Бурхан хүн бүрийг шавдуулдаг. Хэрвээ хүн Бурханы зохион байгуулалтаас ангижрахыг хүсэж зүрхэлбэл үр дагавар нь төсөөлөхийн аргагүй аймшигтай байх болно. Тэгэхээр энэ нь, эдгээр үгээс гэгээрэл, гэрэлтүүлэлт мэдэрсэн бүх хүнд Бурханы захиргааны зарлигийг илүү сайн ойлгуулж, Түүний сүр жавхланд халдаж болохгүй гэдгийг ч бас ойлгуулж, улмаар илүү хашир, тууштай агаад нар салхинд элэгдэж, тэсгим хүйтний заналхийллийг сөрөн зогсдог нарс мод шиг ногоон болж, цэцэглэн дэлгэрч буй байгалийн ногоон амин чанарт хувь нэмрээ оруулсаар байхад хүргэдэг. Энэ хэсэгтэй тулгараад ихэнх хүн нэг төрлийн ээдрээтэй байдалд орчихсон мэт будилж гүйцдэг; учир нь Бурханы үгийн агуулга харьцангуй хурдан өөрчлөгддөг тул өөрсдийн завхарсан зан чанарыг ойлгохоор оролдох үедээ арван хүний ес нь төөрдөг байшинд ордог. Ирээдүйд илүү төвөггүй ажиллаж, бүх хүний зүрх сэтгэл дэх эргэлзээг арилгаж, бүх хүнийг Бурханы итгэмжит байдалд улам бүр итгүүлэхийн тулд Тэрээр тухайн хэсгийн төгсгөлд: “Намайг үнэхээр хайрладаг хүн

нэг бүр Миний сэнтийн өмнө заавал эргэж ирнэ” хэмээн цохон тэмдэглэсэн. Тиймээс Түүний хэдэн сарын ажлыг туулсан хүмүүсийн оюун санаан дахь зарим нэг санаа зовнил нэн даруй намжсан. Үүнээс гадна, агаарт зүүгдсээр байсан тэдний зүрх сэтгэл хүнд чулуу газарт унаж буй мэтээр урьд нь нэгэнтээ байсан байрандаа буцан очдог. Тэд хувь заяаныхаа талаар бодохоо больдог; түүнчлэн, Бурхан цаашид дэмий хоосон үг хэлэхгүй гэж итгэдэг. Хүмүүс өөрсдийгөө зөвтгөдөг учраас Бурханд дээд зэргийн үнэнч байдал харуулж байна гэдэгтээ итгэдэггүй ганц ч хүн байхгүй; ийм учраас Бурхан илүү сайн үр дүнд хүрэхийн тулд “үнэхээр” гэдгийг зориуд цохон тэмдэглэдэг. Энэ нь Өөрийн ажлын дараагийн алхмын замыг засаж, суурийг тавихын төлөө байдаг билээ.

3-Р БҮЛЭГ

Өнөөдөр Нигүүлслийн эрин үе биш, өршөөлийн эрин үе ч биш, харин Бурханы ардуудын илчлэгддэг Хаанчлалын эрин үе буюу Бурхан аливааг шууд бурханлаг чанараар хийдэг эрин үе юм. Тиймээс Бурханы үгийн энэхүү бүлгээр Бурхан Өөрийнх нь үгийг хүлээн авдаг бүх хүнийг сүнсний ертөнц рүү хөтөлдөг. Эхний догол мөрт Тэрээр эдгээр бэлтгэлийг урьдчилан хийсэн бөгөөд хэрвээ хүн Бурханы үгийн талаар мэдлэгтэй бол учгийг даган мөрдөж, Бурхан Өөрийнхөө ардуудад юу хийж гүйцэтгэхээр хүсэж байгааг шууд ухаарах болно. Хүмүүсийг урьд нь “үйлчлэл үзүүлэгчид” гэх нэршлийг ашиглан туршсан бөгөөд өнөөдөр тэднийг шалгалтад оруулсны дараа тэдний сургалт албан ёсоор эхэлдэг. Нэмж хэлэхэд, өнгөрсөн үеийн үгийн сууринд үндэслэн хүмүүс Бурханы ажлын талаар илүү их мэдлэгтэй байх ёстой бөгөөд үг болон хүн, мөн Сүнс болон хүнийг салшгүй нэгэн бүхэл буюу нэг ам, нэг зүрх сэтгэл, нэг үйлдэл, нэг эх сурвалж гэж үзэх ёстой. Энэхүү шаардлага нь бүтээлийн цаг үеэс хойш хүнд Бурханы тавьсан хамгийн өндөр шаардлага юм. Үүнээс, Бурхан хичээл чармайлтынхаа нэг хэсгийг Өөрийн ардуудад зарцуулахыг хүсдэгийг, тэдэнд зарим нэг тэмдэг, гайхамшиг харуулахыг хүсдэгийг, бүр ч чухал нь Тэрээр бүх хүнийг Бурханы бүхий л ажил болон үгэнд дуулгавартай байлгахыг хүсдэгийг харж болно. Нэг талаар Бурхан Өөрөө гэрчлэлээ хамгаалдаг, нөгөө талаар Тэр Өөрийнхөө ардуудад шаардлага тавьж, олон нийтэд Өөрийн захиргааны зарлигийг шууд гаргасан: Тиймээс, та нар Миний ард гэж нэрлэгдсэн болохоор юмс урьдынх шигээ байхаа больсон; та нар Миний Сүнсний айлдваруудыг сонсож, дуулгавартай даган, Миний ажлыг ойрхон дагах ёстой; Миний Сүнс болон Миний махбодыг салгаж болохгүй, учир нь Бид бол төрөлхөөсөө нэг агаад угаасаа салшгүй билээ. Бие махбодтой болсон Бурханыг хүмүүс үл ойшоохоос сэргийлэхийн тулд “учир нь Бид бол төрөлхөөсөө нэг агаад угаасаа салшгүй” гэх үгийг энд дахин нэгэнтээ онцолсон байна; ингэж үл ойшоох нь хүний алдаа учраас үүнийг Бурханы захиргааны зарлигт дахин нэгэнтээ жагсаасан. Дараа нь Бурхан

хүмүүст, Бурханы захиргааны зарлигийг зөрчихийн үр дагаврын талаар юу ч нуулгүйгээр мэдэгдэж, “Тэд хохирол амсаж, өөрсдийнхөө гашуун зовлонгийн аяганаас л уух болно” хэмээн хэлсэн билээ. Хүн сул дорой учраас эдгээр үгийг сонссоны дараа зүрх сэтгэлдээ өөрийн эрхгүй Бурханаас илүү их болгоомжлох болсон, учир нь “гашуун зовлонгийн аяга” гэдэг нь хүмүүсийг хэсэг зуур тунгаан бодуулахад хангалттай юм. Бурханы ярьдаг энэхүү “гашуун зовлонгийн аяганы” талаар хүмүүст олон тайлбар байдаг: үгээр шүүгдэх, хаанчлалаас хөөгдөх, хэсэг зуур тусгаарлагдах, эсвэл махан биеэ Сатанаар завхруулж, муу ёрын сүнсэнд эзэмдүүлэх, Бурханы Сүнсэнд хаягдах, эсвэл махан биеэ эцэс болгож, Үхэгсдийн орон руу цөлөгдөх. Эдгээр тайлбар нь хүмүүсийн бодол санаагаар хүрч болох зүйл тул хүмүүс төсөөллөөрөө тэдгээрээс хэтрэн гарч чаддаггүй. Гэхдээ Бурханы бодол хүнийхтэй адилгүй; өөрөөр хэлбэл, “гашуун зовлонгийн аяга” гэдэг нь дээрх зүйлсийн алийг ч хэлдэггүй, харин Бурханы харьцалтыг хүлээн авсны дараах хүмүүсийн Бурханы тухай мэдлэгийн хэмжээг хэлдэг. Үүнийг илүү тодорхой хэлбэл, хүн Бурханы Сүнс болон Түүний үгийг дур зоргоороо салгах үед, эсвэл үг болон хүнийг юм уу Сүнс болон Өөрийгөө хувцасладаг махан биеийг нь салгах үед энэ хүн Бурханы үгээс Бурханыг мэдэх чадваргүйгээр зогсохгүй, хэрвээ Бурханыг бага зэрэг сэжиглэх юм бол цаг ямагт сохор болно. Хүмүүсийн төсөөлдөг шигээр тэднийг шууд тасдан хаядаггүй; харин ч тэд аажмаар Бурханы гэсгээлтэд унадаг—өөрөөр хэлбэл, тэд асар их гамшигт унаж, хэн ч тэдэнтэй таарч тохирдоггүй ба тэд муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн мэт, хаашаа ч явсан юм мөргөж байдаг толгойгүй ялаа шиг л байдаг. Тэгсэн ч гэсэн тэд орхин явах чадваргүй хэвээр байдаг. Тэдний зүрх сэтгэлд юмс дүрслэн хэлэхийн аргагүй хэцүү бэрх байж, зүрх сэтгэлд нь үгээр хэлшгүй их зовлон байгаа мэт байдаг атал амаа ангайж ч чадалгүй, бүхий л өдрийг ухаан мэдрэлгүйгээр өнгөрүүлээд, Бурханыг мэдэрч чаддаггүй. Эдгээр нөхцөл байдлын дор Бурханы захиргааны зарлиг тэднийг заналхийлдэг, ингэснээр тэд ямар ч таашаалгүй байгаа хэр нь чуулганыг орхин явж зүрхэлдэггүй—үүнийг “дотоод болон гадаад талын дайралт” гэж нэрлэдэг бөгөөд хүмүүсийн хувьд үүнийг тэвчихэд асар хэцүү байдаг. Энд хэлсэн зүйл хүмүүсийн үзлээс өөр—учир нь тийм нөхцөл байдалд тэд Бурханыг эрж хайхаа мөн л мэддэг ба Бурхан тэднээс нүүр буруулах үед энэ нь тохиолддог, үүнээс ч чухал нь, яг үл итгэгчийн адилаар тэд Бурханыг огт мэдэрч чаддаггүй. Бурхан тийм хүмүүсийг шууд авардаггүй; тэдний гашуун зовлонгийн аяга хоосрох үе нь тэдний эцсийн өдөр ирсэн үе юм. Гэхдээ энэ мөчид тэд Бурханы хүслийг эрж хайсаар байж, үүнийг дахиад жаахан эдлэхийг хүсдэг—гэхдээ ямар нэгэн онцгой нөхцөл байдал байхгүй л бол энэ цаг үе өнгөрсөн үеэс өөр билээ.

Үүний дараа Бурхан бүх хүнд эерэг талуудыг ч бас тайлбарлаж, тийнхүү тэд дахин нэгэнтээ амийг олж авдаг—учир нь өнгөрсөн үед Бурхан, үйлчлэл үзүүлэгчдэд ямар ч амь байхгүй гэж хэлсэн боловч өнөөдөр гэнэтхэн “доторх амийн” талаар ярьсан. Амийн тухай ярьснаар л хүмүүс, өөрсдийнх нь дотор

Бурханы амь байж болох юм байна гэдгийг мэдсэн. Ийм маягаар Бурханыг гэх тэдний хайр хэд дахин нэмэгдэж, тэд Бурханы хайр, өршөөлийн талаар илүү их мэдлэгийг олж авдаг. Тиймээс эдгээр үгийг харсны дараа бүх хүн урьдын алдаандаа гэмшиж, нуцаар харууслын нулимс урсгасан. Ихэнх нь бас Бурханыг сэтгэл хангалуун байлгах ёстой гэж чимээгүйхэн шийдсэн юм. Заримдаа Бурханы үг хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг нэвт хатгадаг болохоор хүмүүсийн хувьд тэдгээрийг хүлээн авахад бэрх, амар тайван байхад хэцүү байдаг. Заримдаа Бурханы үг чин үнэнч агаад үнэн сэтгэлийн байж, хүмүүсийн зүрх сэтгэлийг дулаацуулдаг, тэгснээр хүмүүс тэдгээрийг уншсаныхаа дараа, олон жил төөрсөн хурга эхийгээ дахин харж байгаа мэт байдаг. Тэгээд нүдэнд нь нулимс цийлгэнэж, сэтгэл хөдлөлд автан, өөрсдийгөө Бурханы тэвэрт аваачихаар байж сууж ядан, эхэр татан уйлж, үнэнч зангаа Бурханд харуулахын тулд олон жилийн турш зүрх сэтгэлд нь байсан үгээр дүрслэхийн аргагүй өвдөлт шаналлыг гаргадаг. Хэдэн сарын туршилтын улмаас тэд бага зэрэг мэдрэмтгий болж, дөнгөж сая сэтгэл санааны цочролд орсон юм шиг, мөн олон жилийн турш хэвтэрт байсан өвчтэй хүн мэт байдаг. Тэднийг Бурханы үгэнд тууштай итгүүлэхийн тулд Бурхан дараах үгийг олон удаа онцлон тэмдэглэсэн байдаг: “Ажлынхаа дараагийн алхмыг саад бартаагүй, төвөггүй урагшлуулахын тулд Би Өөрийн гэрт байгаа хүмүүсийг туршихдаа үгийн цэвэршүүлэлт хэрэглэдэг.” Энд Бурхан “Өөрийн гэрт байгаа хүмүүсийг турших” гэж хэлсэн; эдгээрийг сайтар уншвал, хүмүүс үйлчлэл үзүүлэгч болж үйлдэх үедээ Бурханы гэр доторх хүмүүс хэвээр байдаг гэдгийг мэдэж болно. Түүнчлэн, эдгээр үг нь “Бурханы ардууд” хэмээх нэрэнд хандах Бурханы үнэн сэтгэлийг онцолж, хүмүүсийн зүрх сэтгэлд тодорхой хэмжээний тайтгарал авчирдаг. Тэгвэл, Бурханы үгийг уншсаны дараа хүмүүст байдаг олон илрэлийг, эсвэл “Бурханы ардууд” гэх цол хараахан илчлэгдээгүй байх үеийг Бурхан яагаад ахин дахин заан үзүүлдэг юм бэ? Энэ нь, Бурхан бол хүний зүрх сэтгэлийн гүнийг хардаг Бурхан мөн гэдгийг л харуулахын төлөө байдаг бус уу? Энэ нь учир шалтгааны зөвхөн нэг хэсэг—энд энэ нь ердөө хоёрдугаар зэргийн ач холбогдолтой. Бурхан, бүх хүнийг бүрэн үнэмшүүлэхийн тулд, мөн Бурханы үгээс хүн бүр хангалтгүй байдлаа мэдэж, амьтай холбоотой урьдын дутагдлаа мэдэж авахын тулд, үүнээс гадна ажлын дараагийн үе шатны төлөөх суурийг тавихын тулд ийнхүү хийдэг. Хүмүүс өөрсдийгөө мэдсэн сууринд л үндэслэн Бурханыг мэдэхээр хичээж, Бурханыг дуурайхаар эрэлхийлж чадна. Эдгээр үгээс болоод хүмүүс сөрөг, идэвхгүй байснаа эерэг, идэвх санаачилгатай болон өөрчлөгддөг бөгөөд энэ нь Бурханы ажлын хоёр дахь хэсгийн үндсийг суулгадаг. Ажлын энэ үе шатыг суурь болгосноор Бурханы ажлын хоёр дахь хэсэг хялбар хэрэг болж, хамгийн өчүүхэн жаахан хичээл чармайлт шаарддаг гэж хэлж болно. Тиймээс хүмүүс өөрсдийн зүрх сэтгэл доторх уйтгар гунигаа үлдэн хөөж, эерэг агаад идэвх санаачилгатай болох үед Бурхан энэ боломжийг ашиглан Өөрийнхөө ардуудад өөр шаардлага тавьдаг: “Миний үг хэдийд ч, хаана ч хэлэгдэж, илэрхийлэгддэг тул та нар ч бас цаг ямагт

Миний өмнө өөрсдийгөө мэдэж байх ёстой. Учир нь, өнөөдөр бол эцсийн эцэст өнгөрсөн үетэй адилгүй бөгөөд цаашид чи хүссэн бүхнээ биелүүлж чадахгүй. Харин чи Миний үгийн удирдамж дор өөрийнхөө биеийг захирах чадвартай байх ёстой; чи Миний үгийг түшиг тулгуураа болгон ашиглах ёстой ба болчимгүй аашилж болохгүй.” Энд Бурхан үндсэндээ “Миний үг” гэдгийг онцлон тэмдэглэсэн; өмнө нь ч гэсэн Тэр олон удаа “Миний үг” гэж дурдаж байсан, тиймээс хүн бүр үүнд өөрийн эрхгүй анхаарал хандуулдаг. Тиймээс энэ нь Бурханы ажлын дараагийн үе шатны гол цөмийг илтгэдэг: Бүх хүн Бурханы үгэнд анхаарлаа хандуулах ба өөр ямар ч хайр байж болохгүй. Бурханы амнаас гарсан үгийг бүгд нандигнах ёстой ба тэдгээрийг хөнгөн хуумгай авч үзэх ёсгүй; тийнхүү нэг хүн Бурханы үгийг уншиж, олон хүн амен хэмээн хэлж, дуулгавартай байдаг чуулганы урьдын нөхцөл байдал төгсгөл болох болно. Тухайн үед хүмүүс Бурханы үгийг мэдээгүй, харин тэдгээрийг өөрсдийгөө хамгаалах зэвсэг мэт авч үзсэн. Үүнийг өөрчлөхийн тулд Бурхан илүү өндөр, шинэ шаардлагыг газар дээр хүнд тавьсан билээ. Бурханы өндөр стандарт, хатуу чанд шаардлагуудыг харсныхаа дараа хүмүүс сөрөг, идэвхгүй болдгийг болиулахын тулд Бурхан: “Нэгэнт юмс өнөөдрийн ийм нөхцөл байдалд хүрсэн учраас та нар өнгөрсөн үеийн үйл хэрэг, үйлдэлдээ хэтэрхий их шаналж, харамсах хэрэггүй. Миний уужим сэтгэл далай тэнгис, тэнгэр мэт хязгааргүй—хүний чадвар болон Миний талаарх мэдлэгийг Би алган дээрээ тавьсан мэт мэддэг бус уу?” хэмээн хэлж олон удаа хүмүүсийг зоригжуулсан. Эдгээр чин үнэнч, үнэн сэтгэлийн үг хүмүүсийн оюун ухааныг гэнэт нээж, тэднийг цөхрөлөөс Бурханы төлөөх хайр луу, мөн эерэг, идэвх санаачилгатай байдал руу нэн даруй аваачсан, учир нь Бурхан хүмүүсийн зүрх сэтгэл дэх сул талыг шүүрэн авч үгээ хэлдэг билээ. Энэ тухай мэдэлгүйгээр хүмүүс өөрсдийн урьдын үйлдлүүдээс болж Бурханы өмнө үргэлж эвгүйцдэг бөгөөд харууслаа ахин дахин илэрхийлдэг. Тиймээс Бурхан эдгээр үгийг тун хялбархан, хэвийн байдлаар илчилдэг, ингэснээр хүмүүст Бурханы үг бол хүйтэн хөндий, үхмэл биш, харин хатуу агаад зөөлөн, тод томруун агаад бодитой санагддаг.

Бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэл Бурхан сүнсний ертөнцөөс хүнд зориулан бүхнийг чимээгүйхэн зохицуулсан бөгөөд сүнсний ертөнцийн үнэнийг хүнд хэзээ ч дүрслэн өгүүлээгүй юм. Гэсэн ч, өнөөдөр Бурхан тэнд явагддаг тулааныг гэнэт өгүүлсэн нь аяндаа хүмүүсийг будилуулж, Бурхан бол гүн гүнзгий агаад ойлгохын аргагүй юм гэдгийг тэдэнд улам илүү мэдрүүлж, тэдний хувьд Бурханы үгийн эх сурвалжийг олоход бүр ч хэцүү болгож орхидог. Сүнсний ертөнц байлдааны бэлэн байдалд орсон байгаа нь бүх хүнийг сүнс рүү аваачдаг гэж хэлж болно. Энэ бол ирээдүйн ажлын эхний шийдвэрлэх чухал хэсэг бөгөөд хүмүүсийг сүнсний ертөнц рүү оруулах учиг юм. Бурханы ажлын дараагийн алхам нь үндсэндээ сүнс рүү чиглэдгийг үүнээс харж болох бөгөөд үүний үндсэн зорилго нь бүх хүнийг махбод доторх Бурханы Сүнсний гайхалтай үйл хэргийн талаар илүү их мэддэг болгож, улмаар Бурханд үнэнч бүх хүнд Сатаны мунхаг байдал болон уг

чанарын талаар илүү их мэдлэг өгөх явдал юм. Хэдийгээр тэд сүнсний ертөнцөд төрөөгүй боловч тэдэнд Сатаныг нүдээрээ харсан мэт санагдах бөгөөд тэдэнд ийм мэдрэмж төрөнгүүт Бурхан үг хэлэх өөр арга барил руу даруй шилждэг—хүмүүс иймэрхүү сэтгэлгээтэй болмогц Бурхан: “Яагаад Би та нарыг ийнхүү яаран сургаж байна вэ? Яагаад Би та нарт сүнсний ертөнцийн бодит баримтыг хэлж өгдөг вэ? Яагаад Би та нарт ахин дахин сануулж, захидаг вэ?” гэж асуудаг. Гэх мэтчилэн бүхэл бүтэн цуврал асуулт нь хүмүүсийн оюун ухаанд олон асуулт төрүүлдэг: Яагаад Бурхан ийм өнгөөр ярьдаг юм бэ? Яагаад Тэр, сүм барьж байх үед хүмүүст тавьсан шаардлагуудынхаа талаар биш, харин сүнсний ертөнцийн хэрэг явдлын талаар ярьдаг юм бэ? Яагаад Бурхан нууцуудыг илчилснээр хүмүүсийн үзлийг тас цохидоггүй юм бэ? Зүгээр л бага зэрэг анхааралтай хянуур байснаар хүмүүс Бурханы ажлын алхмуудын талаар бага зэрэг мэдлэгтэй болдог болохоор хожим уруу таталттай тулгарах үед тэдний дотор Сатаныг үзэн ядах жинхэнэ мэдрэмж төрнө. Хожим шалгалттай тулгарах үедээ ч гэсэн тэд мөн л Бурханыг мэдэж, Сатаныг илүү гүн гүнзгий жигшиж чадах бөгөөд тийнхүү Сатаныг хараана.

Эцэст нь Бурханы хүсэл хүнд бүрэн илчлэгдэнэ: “миний үг болгоныг сүнсэн дотроо үндэслүүлж, цэцэглүүлж, жимслүүлж, бүр ч чухал нь илүү их жимс гаргах хэрэгтэй. Учир нь Миний шаарддаг зүйл бол гоёмсог цэцэгс биш, харин элбэг дэлбэг үр жимс буюу мууддаггүй үр жимс юм.” Өөрийнхөө ардуудаас Бурханы шаардсан олон удаагийн шаардлагуудаас энэ нь хамгийн иж бүрэн, гол зүйл бөгөөд үүнийг илэн далангүй байдлаар хэлсэн. Би хэвийн хүн чанараар ажилладаг байдлаас бүрэн бурханлаг чанараар ажилладаг байдалд шилжсэн; тиймээс урьд нь Би ний нуугүй хэлсэн үгэндээ ямар нэгэн нэмэлт тайлбар нэмэх хэрэггүй байсан бөгөөд ихэнх хүн Миний үгийн утгыг ойлгож чадсан. Үүний үр дүнд, тухайн үед хүмүүсээс Миний үгийг мэдэж, бодит байдлын талаар ярих чадвартай байхыг л шаардаж байсан юм. Гэхдээ энэ үе шат бол маш өөр. Миний бурханлаг чанар хяналтыг бүрэн авч, хүн чанар ажиллах ямар ч орон зай үлдээгээгүй. Тиймээс Миний ардуудын дундах хүмүүс Миний үгийн жинхэнэ утгыг ойлгохыг хүсвэл тэдэнд туйлын хэцүү байдаг. Зөвхөн Миний айлдваруудаар л дамжуулан тэд гэгээрэл, гэрэлтүүлэлт олж авч чадах бөгөөд энэ сувгаар дамжихгүй л бол Миний үгийн зорилгыг ухаарна гэсэн аливаа бодол нь хий хоосон мөрөөдөл болно. Миний айлдваруудыг хүлээн авсныхаа дараа бүх хүн Миний талаар асар их мэдлэгтэй байх үе нь Миний ардууд Намайг амьдран харуулах үе бөгөөд энэ нь махбод дахь Миний ажил дууссан үе, Өөрийн бурханлаг чанарыг махбодоор бүрэн амьдран харуулсан үе билээ. Энэ мөчид бүх хүн махбод дахь Намайг мэдэж, Бурхан махбодоор илэрсэн гэж үнэхээр хэлж чадах бөгөөд үр жимс нь энэ байх болно. Бурхан чуулган байгуулахаас залхаж эхэлсэн гэдгийг энэ нь улам их нотолдог—өөрөөр хэлбэл, “хүлэмжин дэх цэцэгс одод шиг тоо томшгүй олон агаад бахдан биширсэн олны сэтгэлийг татдаг хэдий ч хатаж гандмагцаа Сатаны овжин явуулга шиг салбайж навсайдаг ба хэн ч тэдгээрийг сонирхдоггүй.” Хэдийгээр чуулганыг

байгуулах цаг үед Бурхан бас биечлэн ажилласан боловч Тэрээр үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан учраас өнгөрсөн үеийн хэрэг явдлуудыг дурсан санадаггүй. Хүмүүсийн өнгөрснөө эргэн санадгийг болиулахын тулд Тэрээр “Сатаны овжин явуулга шиг салбайж навсайдаг” хэмээх үгийг ашигласан нь Бурхан дүрэм журмыг мөрддөггүй гэдгийг харуулдаг. Зарим хүн Бурханы хүслийг буруугаар тайлбарлаж, “Энэ нь Бурханы Өөрийн хийсэн ажил байтал Тэр яагаад ‘цэцэгсийг хатаж гандмагц нь хэн ч тэдгээрийг сонирхдоггүй’ гэж хэлсэн юм бэ?” хэмээн асууж магадгүй. Эдгээр үг хүмүүст илчлэл өгдөг. Хамгийн чухал нь тэдгээр нь бүх хүнийг шинэ, үнэн зөв, эхлэлийн цэгтэй болгодог; тэр үед л тэд Бурханы хүслийг хангалуун болгож чадна. Эцэстээ Бурханы ардууд үнэн зөв, хүчинд автаагүй, өөрсдийнх нь зүрх сэтгэлээс гарсан магтаалыг Бурханд өгч чадна. Энэ бол Бурханы 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөний гол цөмд байдаг зүйл юм. Өөрөөр хэлбэл, энэхүү 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөний биелэлт нь энэ: бүх хүнд бие махбодтой болсон Бурханы ач холбогдлыг мэдүүлж—Бурхан махбод болсныг буюу махбод дахь Бурханы үйл хэргийг тэдэнд бодитоор мэдүүлэх явдал—ингэснээр тэд тодорхойгүй Бурханыг үгүйсгэж, мөнхөөс мөнхөд үнэхээр, бодитоор оршин байсан өнөөдрийн бас өчигдрийн, үүнээс ч илүүтэйгээр маргаашийн Бурханыг мэдэх юм. Тэр үед л Бурхан амралтад орно!

4-Р БҮЛЭГ

Бүх хүн сөрөг байдлаас эерэг байдал руу шилжсэнийхээ дараа биеэ тоож, хяналтаа алдахыг болиулахын тулд айлдварынхаа сүүлчийн бүлэгт Бурхан, Өөрийн ардуудад тавих хамгийн өндөр шаардлагынхаа талаар нэгэнтээ ярьсан—Өөрийнхөө удирдлагын төлөвлөгөөний энэ үе шатан дахь Өөрийн хүслийн талаар Бурхан хүмүүст нэгэнтээ хэлсэн—Тэрээр Өөрийнх нь үгийг тунгаан бодож, эцэстээ Бурханы хүслийг хангахаар шийдэхэд нь туслахын тулд тэдэнд боломж олгосон юм. Хүмүүсийн нөхцөл байдал эерэг байх үед Бурхан хэрэг явдлын нөгөө талын тухай асуултуудыг нэн даруй асууж эхэлдэг. Тэрээр хүмүүсийн хувьд танин мэдэхэд хэцүү цуврал асуулт тавьдаг: “Намайг хайрлах та нарын хайр хольцтой юу? Надад өгсөн үнэнч байдал чинь цэвэр, чин сэтгэлийнх байсан уу? Миний талаарх та нарын мэдлэг үнэн байсан уу? Та нарын зүрх сэтгэлд Би хэр их зай эзэлж байсан бэ?” гэх мэт. Энэ догол мөрийн эхний хэсэг дэх хоёр зэмлэлийг үл тооцвол үлдсэн хэсэг нь бүхэлдээ асуултаас бүрддэг. Ялангуяа “Миний айлдварууд та нарын дотор зорьсондоо хүрсэн үү?” гэх нэг асуулт нь тун тохиромжтой юм. Энэ нь хүмүүсийн зүрх сэтгэлийн гүн дэх хамгийн нууц зүйлийг онож, “Бурханыг гэх хайр минь үнэхээр үнэнч бил үү?” хэмээн өөрсдөөсөө өөрийн эрхгүй асуухад хүргэдэг. Хүмүүс үйлчилж байсан урьдын туршлагуудаа өөрийн эрхгүй зүрх сэтгэлдээ дурсдаг: Тэд өөрсдийгөө уучилдаг, өөрсдийгөө зөвтгөдөг,

өөрсдийгөө чухалчилдаг байдал, маадгар, ихэрхүү, бардам занд автсан байлаа. Тэд торонд баригдсан том загас мэт байсан ба энэхүү торонд унасны дараа тэдний хувьд өөрсдийгөө чөлөөлөхөд амаргүй байв. Түүнчлэн тэд байнга цадиггүй байж, Бурханы хэвийн хүн чанарыг үргэлж мэхэлж, хийсэн бүхэндээ өөрсдийгөө эн тэргүүнд тавьдаг байлаа. “Үйлчлэл үзүүлэгч” гэж нэрлэгдэхээсээ өмнө тэд эрч хүчээр дүүрэн барын зулзага шиг байв. Хэдийгээр тэд өөрсдийнхөө анхаарлыг амь руу бага зэрэг хандуулж байсан боловч заримдаа хийсэн дүр үзүүлдэг; боолуудын адилаар Бурханд хайхрамжгүй ханддаг байлаа. Үйлчлэл үзүүлэгч гэж илчлэгдэж байх хугацаандаа тэд сөрөг болж, ард хоцорч, уй гашуугаар дүүрсэн, мөн Бурханы талаар гомдоллож, сэтгэлээр унан толгойгоо унжуулдаг байсан гэх мэт. Тэдний өөрсдийнх нь гайхалтай, сэтгэл хөдөлгөм түүхүүдийн алхам бүр оюун санаанд нь хадгалагддаг. Тэдний хувьд бүр унтахад ч хэцүү болдог ба тэд өдрийн цагийг ухаан мэдрэлгүй өнгөрүүлдэг. Тэд хоёр дахь удаагаа Бурханд таягдуулан хаягдаж, Үхэгсдийн орон руу унасан бөгөөд зугтах чадваргүй байгаа мэт санагддаг. Хэдийгээр Бурхан эхний догол мөрөнд хэдхэн хэцүү асуулт л тавьсан боловч сайтар уншвал, Бурханы зорилго нь асуулт тавихын төлөө л эдгээр асуултыг асуусан хэрэг биш гэдгийг тэдгээр нь харуулдаг; тэдгээрт илүү дэлгэрэнгүй тайлбарлах ёстой, гүн гүнзгий түвшний утга учир агуулагддаг.

Өнөөдөр бол эцсийн эцэст өнөөдөр бөгөөд өчигдөр аль хэдийн өнгөрсөн тул өнгөрснөө дурсан санах ямар ч хэрэггүй гэж Бурхан нэгэнтээ хэлсэн атал яагаад Тэрээр энд байгаа эхний өгүүлбэрт хүмүүсээс асуулт асууж, тэднийг өнгөрснөө дурсан санахад хүргэсэн бэ? Бодоод үз: Яагаад Бурхан өнгөрснөө дурсан санагалзахгүй байхыг хүмүүсээс хүсдэг ч өнгөрснөө эргэн санахыг тэднээс бас хүсдэг юм бэ? Бурханы үгэнд алдаа байдаг юм гэж үү? Эдгээр үгийн эх сурвалж буруу юм гэж үү? Угаасаа Бурханы үгэнд анхаарал хандуулдаггүй хүмүүс тийм гүн гүнзгий асуулт асуухгүй. Гэхдээ одоохондоо энэ талаар ярих хэрэггүй. Эхлээд Би дээр буй “яагаад” гэх эхний асуултыг тайлбарлая. Мэдээж, хоосон үг хэлдэггүй гэдгээ Бурхан нэгэнтээ хэлснийг хүн бүр мэдэж байгаа. Хэрвээ Бурханы амнаас үг гарсан л бол тэдгээрт зорилго болон ач холбогдол бий—энэ нь асуудлын голыг хөнддөг. Хүмүүсийн хамгийн том алдаа дутагдал бол өөрсдийн ёрын муу замыг өөрчлөх чадваргүй байдал болон хуучин уг чанарыг нь өөрчлөхөд хэцүү байдаг явдал юм. Хүмүүст өөрсдийг нь илүү нэгд нэггүй, бодитоор мэдүүлэхийн тулд Бурхан эхлээд тэднээр өнгөрснийг нь дурсан сануулдаг ба ингэснээр тэд өөрсдийгөө илүү гүн гүнзгий эргэцүүлж, тэрчлэн Бурханы ганц ч үг дэмий хоосон байдаггүй, Бурханы бүх үг өөр өөр хүмүүст өөр өөр түвшинд хэрэгждэг гэдгийг мэдэж авч болох юм. Өмнө нь, хүмүүстэй Бурханы харьцаж байсан байдал тэдэнд Бурханы талаар бага зэрэг мэдлэг олгож, Бурханд хандах чин сэтгэлийг нь бага зэрэг үнэнч болгосон. “Бурхан” хэмээх үг хүмүүс болон тэдний зүрх сэтгэлд ердөө 0.1 хувийг л эзэлдэг. Ийм хэмжээнд хүрэх нь Бурхан асар их хэмжээний аврал явуулсан гэдгийг харуулдаг. Энэ бүлэг хүмүүс буюу агуу улаан лууд дарлагдаж,

Сатанд эзэмдүүлсэн бүлэгт Бурхан ийм ихийг гүйцэтгэсэн болохоор тэд хүссэнээрээ хийж зүрхэлдэггүй гэж хэлэх нь зүйтэй юм. Яагаад гэвэл, Бурханы хувьд Сатанаар эзэмдүүлсэн хүмүүсийн зүрх сэтгэлийг зуун хувь эзлэх боломжгүй билээ. Дараагийн алхмын үеэр Бурханы талаарх хүмүүсийн мэдлэгийг өсгөхийн тулд Бурхан, өнгөрсөн үеийн үйлчлэл үзүүлэгчдийн нөхцөл байдлыг өнөөдрийн Бурханы ардуудын нөхцөл байдалтай харьцуулж, улмаар хүмүүсийг илүү их ичээх тодорхой ялгааг бий болгосон юм. Бурханы хэлсэнчлэн “өөрсдийн ичгүүрийг нуух газаргүй.”

Тэгвэл Бурхан зүгээр л асуулт тавихын төлөө асуулт асуугаагүй гэж Би яагаад хэлсэн бэ? Эхнээс нь дуустал сайтар уншвал, Бурханы тавьсан асуултуудыг бүрэн тайлбарлаагүй хэдий ч тэдгээр нь бүгд хүмүүсийн Бурханд хандах үнэнч байдал болон Бурханы талаарх мэдлэгийн хэмжээг хэлдэг нь харагддаг; өөрөөр хэлбэл, тэдгээр нь хүмүүсийн өрөвдөлтэй бодит нөхцөл байдлыг хэлсэн ба тэдний хувьд энэ талаар ярихад хэцүү байдаг. Үүнээс, хүмүүсийн биеийн хэмжээ хэтэрхий жаахан, Бурханы талаарх мэдлэг нь хэтэрхий өнгөцхөн, Бурханд хандах үнэнч зан нь хэтэрхий хольцтой, бузар байдгийг харж болно. Бурханы хэлсэнчлэн бараг бүх хүн булингартай усанд загасчилдаг ба тоо бүрдүүлэхийн тулд л тэнд байдаг. Бурхан: “Та нар Миний ардууд байх эрхгүй гэдэгтээ үнэхээр итгэдэг үү?” хэмээн хэлэх үед эдгээр үгийн жинхэнэ утга нь, бүх хүний дундаас нэг нь ч Бурханы ард байхад тохирохгүй гэдэг юм. Гэвч илүү их үр нөлөө үзүүлэхийн тулд Бурхан асуулт асуух аргыг ашигладаг. Энэхүү арга барил нь, хүмүүсийн зүрх сэтгэлийг нэвт сүлбэх хэмжээнд хайр найргүйгээр дайран довтолж, цавчиж, хөнөөж байсан өнгөрсөн үеийн үгээс хавьгүй илүү үр дүнтэй юм. Бурхан: “Та нар Надад үнэнч биш, та нарын үнэнч байдал хольцтой, Би та нарын зүрх сэтгэлд үнэмлэхүй байр эзэлдэггүй… Би чамд нуугдах ямар ч газар үлдээхгүй, учир нь та нарын хэн нь ч Миний ард байхад хангалтгүй” гэх мэтийн муйхар, сонирхолгүй зүйлийг шууд хэлсэн гэж бодоод үз. Та нар энэ хоёрыг харьцуулан үзэж болох бөгөөд агуулга нь адилхан хэдий ч аль алиных нь өнгө аяс өөр. Асуулт ашиглах нь хамаагүй илүү үр дүнтэй. Тиймээс ухаалаг Бурхан эхний өнгө аясыг ашигладаг нь Түүний ярианы ур чадварыг харуулдаг. Энэ нь хүний хүршгүй зүйл тул Бурхан: “Хүмүүс бол Надаар ашиглагддаг багаж хэрэгсэл төдий. Тэдний хоорондох цорын ганц ялгаа гэвэл зарим нь дорд, зарим нь эрхэм нандин байдаг” хэмээн хэлсэнд гайхах юмгүй.

Хүмүүсийг үргэлжлүүлэн уншихын хэрээр Бурханы үг бөөнөөрөө ирж, хүмүүст амьсгаа авах боломж бараг олгодоггүй, учир нь Бурхан хүнд огтхон ч зөөлөн ханддаггүй. Хүмүүсийг дээд зэргээр харамсаж байх үед Бурхан тэдэнд дахин нэгэнтээ ийнхүү анхааруулсан: “Хэрвээ та нар дээрх асуултуудыг огт анзаарахгүй байгаа бол булингартай усанд загасчилж, зүгээр л тоо бүрдүүлж байгааг чинь энэ нь харуулах бөгөөд Миний урьдчилан тогтоосон цагт чи гарцаагүй таягдан хаягдаж, хоёр дахь удаагаа ёроолгүй нүхэнд унана. Энэ бол Миний анхааруулсан үг бөгөөд үүнийг хөнгөн хуумгай авч үзсэн хүмүүс Миний шүүлтэд өртөж, товлосон цагт гай зовлонтой тулгарна.” Ийм үгийг уншаад хүмүүс ёроолгүй нүхэнд хаягдсан үеэ

өөрийн эрхгүй боддог: Тэднийг гай гамшиг заналхийлж, Бурханы захиргааны зарлиг удирдаж, өөрсдийнх нь төгсгөл хүлээж байсан ба тэд урт удаан хугацаанд гутарч, хямран, амархан өвдөж, зүрх сэтгэл доторх уйтгар гунигаа өөр хэнд ч хэлж чадахгүй байсан—үүнтэй харьцуулахад тэд махан биеэсээ салсан нь хамаагүй дээр байх байв… Ингэж бодохоороо тэд өөрийн эрхгүй гутардаг. Тэгээд урьд нь ямар байсан, өнөөдөр ямар байгаа, маргааш ямар байхаа бодохоор тэдний зүрх сэтгэл дэх уй гашуу нэмэгдэж, өөрийн эрхгүй дагжин чичирч эхэлдэг тул тэд Бурханы захиргааны зарлигаас улам их айдаг. “Бурханы ардууд” хэмээх нэр томьёо нь бас ярих арга барил байж болох юм гэж тэдэнд санагдахад зүрх сэтгэл дэх баяр хөөр нь нэн даруй гутрал болон хувирдаг. Бурхан тэднийг цохихын тулд гол сул талыг нь ашиглаж байгаа ба энэ мөчид Тэрээр ажлынхаа дараагийн алхмыг эхлүүлэн, хүмүүсийн оюун санааг үргэлж өдөөн хатгаж, Бурханы үйл хэрэг ойлгохын аргагүй, Бурханд хүрэхийн аргагүй, Бурхан ариун агаад цэвэр, тэд Бурханы ардуудын нэг байхад тохирохгүй хэмээх мэдрэмжийг нь ихэсгэдэг. Үүний үр дүнд тэд хоцорч зүрхлэлгүй, өөрсдийгөө сайжруулахын тулд хичээл чармайлтаа нэмэгдүүлдэг.

Дараа нь хүмүүст сургамж өгч, өөрсдийгөө мэдэж, Бурханыг хүндэлж, Бурханаас эмээхэд тэднийг хүргэхийн тулд Бурхан шинэ төлөвлөгөөгөө эхэлдэг: “Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл олон хүн Миний үгэнд дуулгаваргүй хандаж, улмаар Миний дахин сэргээлтийн урсгалаас зайлуулагдаж, таягдан хаягдсан; эцэст нь тэдний бие мөхөж, сүнс нь Үхэгсдийн орон руу хаягдсан бөгөөд өнөөдөр ч гэсэн тэд хатуу шийтгэлд өртсөөр байгаа. Олон хүн Миний үгийг дагасан боловч тэд Миний гэгээрэл, гэрэлтүүлэлтийн эсрэг явсан … ба зарим нь…” Эдгээр нь бодит жишээ юм. Эдгээр үгэнд Бурхан эрин үеүдийн турш дахь Бурханы үйл хэргийг мэдэгдэхийн тулд Бурханы бүх ардад бодит анхааруулга өгөөд зогсохгүй, мөн сүнсний ертөнцөд тохиолдож байгаа зүйлсийн нэг хэсгийн талаарх дам зураглалыг өгдөг. Энэ нь, Бурханд хандах дуулгаваргүй байдлаас нь ямар ч сайн зүйл гарахгүй гэдгийг хүмүүст мэдэгддэг. Тэд үүрдийн ичгүүрийн тэмдэг болж, Сатаны биелэл, Сатаны хуулбар болно. Бурханы зүрх сэтгэлд, энэ талын утга учир нь хоёрдогч ач холбогдолтой байдаг, учир нь эдгээр үг хүмүүсийг аль хэдийн дагжин чичрүүлж, балмагдуулж орхисон билээ. Үүний эерэг тал нь гэвэл, хүмүүс айн чичрэхдээ ч сүнсний ертөнцийн зарим нэг нарийн учрыг мэдэж авдаг—гэхдээ заримыг нь л олж мэддэг тул Би бага зэрэг тайлбар өгөх ёстой. Сүнсний ертөнцийн хаалганаас, тэнд янз бүрийн сүнс байдгийг харж болно. Гэхдээ зарим нь Үхэгсдийн оронд, зарим нь тамд, зарим нь галт нуурт, зарим нь ёроолгүй нүхэнд байдаг. Энд Би жаахан юм нэмж хэлье. Өнгөцхөн хэлбэл, энэ сүнснүүдийг байгаа газрынх нь дагуу ангилж болно; гэхдээ нарийн ярих юм бол заримтай нь Бурханы гэсгээлт шууд харьцдаг, зарим нь Сатаны хүлээсэнд байдаг ба үүнийг нь Бурхан ашигладаг. Илүү тодорхой хэлбэл, тэдний орчин нөхцөлийн ноцтой байдлаас хамааран гэсгээлт нь өөр байдаг. Одоо Би дахиад жаахан тайлбарлая. Бурханы гарт шууд

гэсгээгддэг хүмүүс газар дээр сүнсгүй байдаг ба тэд дахин төрөх боломжгүй гэсэн үг юм. Сатаны эзэмшил дор буй сүнснүүд буюу “Миний дайснууд болсон” гэж Бурханы хэлсэн дайснууд нь газар дэлхийн хэрэг явдалтай холбоотой байдаг. Газар дээрх янз бүрийн муу ёрын сүнснүүд бүгд Бурханы дайсан, Сатаны зарц бөгөөд тэдний оршин тогтнолын учир шалтгаан нь үйлчлэл үзүүлэх, Бурханы үйл хэргийн товойлгогч болохын тулд үйлчлэл үзүүлэх явдал юм. Тиймээс Бурхан: “Энэ хүмүүс Сатанд олзлогдоод зогсохгүй, мөнхийн нүгэлтнүүд болж, Миний дайснууд болсон ба тэд Намайг шууд эсэргүүцдэг” гэж хэлсэн юм. Дараа нь Бурхан ийм төрлийн сүнс ямархуу төгсгөлтэй байх талаар хүмүүст хэлсэн: “Тэд бол Миний уур хилэнгийн оргил дахь Миний шүүлтийн байнууд.” Бурхан бас тэдний одоогийн нөхцөл байдлыг ийнхүү тодруулсан: “Өнөөдөр ч гэсэн тэд сохор хэвээр байж, харанхуй гяндан дотор байсаар байна.”

Бурханы үгийн үнэн зөв байдлыг хүмүүст харуулахын тулд Бурхан бодит жишээг нотолгоо болгон ашигладаг (Түүний ярьдаг Паулын тохиолдол), ингэснээр Түүний анхааруулга хүмүүст илүү гүн гүнзгий сэтгэгдэл үлдээдэг. Хүмүүс Паулын тухай ярьсан зүйлийг түүх хэмээн үзэхийг болиулж, өөрсдийгөө хөндлөнгийн үзэгчид хэмээн бодохоос сэргийлэхийн тулд, түүнчлэн Бурханаас сурч авсан, хэдэн мянган жилийн өмнө тохиолдсон зүйлсийн талаар сайрхан бардамнахыг нь болиулахын тулд Бурхан Паулын насан туршийн амьдралын туршлагад анхаарлаа төвлөрүүлдэггүй. Харин Бурхан Паулын үр дагавар болон тэр ямар төгсгөлтэй учирсан, Паул яагаад Бурханыг эсэргүүцсэн, яагаад тэгж төгссөн талаар анхаарлаа хандуулдаг. Бурхан, Паулын сайхан итгэл найдварыг эцэст нь хэрхэн үгүйсгэснээ цохон тэмдэглэж, сүнсний ертөнц дэх Паулын нөхцөл байдлыг шууд ил болгоход анхаарсан юм: “Паулыг Бурхан шууд гэсгээдэг.” Хүмүүс мэдрэлгүй хөшүүн, Бурханы үгээс юу ч ухаарах чадваргүй учраас Бурхан (айлдварын дараагийн хэсэгт) тайлбар нэмж, өөр талтай холбоотой асуудлын талаар ярьж эхэлсэн: “Намайг эсэргүүцдэг (Миний махан биеийг эсэргүүцээд зогсохгүй хамгийн чухал нь Миний үгийг, Миний Сүнсийг, өөрөөр хэлбэл, Миний бурханлаг чанарыг эсэргүүцдэг) хэн боловч Миний шүүлтийг махан биедээ хүртэнэ.” Өнгөцхөн хэлэхэд, эдгээр үг дээрхтэй холбоогүй мэт санагдаж, энэ хоёрын хоорондямар ч харилцан хамаарал харагддаггүй боловч бүү сандар: Бурханд Өөрийн гэсэн зорилго бий; “дээрх жишээ үүнийг батална” хэмээх энгийн үг нь илт хамааралгүй хоёр асуудлыг харилцан холбодог—энэ нь Бурханы үгийн ухаалаг байдал юм. Тиймээс, Паулын тухай хүүрнэлээр дамжуулан хүмүүсийг гэгээрүүлдэг тул өмнөх болон дараах бичвэрийн хоорондох холбооноос үүдэн, мөн Паулын өгсөн сургамжаар дамжуулан тэд Бурханыг мэдэхээр бүр ч их эрэлхийлдэг бөгөөд эдгээр үгийг хэлснээр Бурханы хүрэхийг хүссэн үр нөлөө яг энэ юм. Дараа нь Бурхан хүмүүсийн амийн оролтыг тусламж болон гэгээрлээр хангах зарим нэг үгийг хэлсэн. Миний хувьд энэ талаар ярих хэрэггүй; эдгээр зүйлийг ойлгоход амархан юм гэж чамд санагдана. Гэхдээ, Бурханы “Намайг хэвийн хүн чанараар ажиллаж байхад

ихэнх хүмүүс Миний уур хилэн, сүр жавхлантай аль хэдийн хүчээ үзсэн ба Миний мэргэн ухаан, зан чанарыг аль хэдийн бага зэрэг мэдсэн. Өнөөдөр Би бурханлаг чанараар шууд ярьж, үйлддэг бөгөөд Миний уур хилэн, шүүлтийг өөрсдийн нүдээр харах зарим хүн бас бий; түүнчлэн шүүлтийн эрин үеийн хоёр дахь хэсгийн үндсэн ажил бол Өөрийн бүх ардад Өөрийн махан биеэр хийх үйл хэргийг шууд мэдэгдэж, та нарт бүгдэд нь Өөрийн зан чанарыг шууд харуулах явдал юм” хэмээн хэлсэн үгийг Би тайлбарлах ёстой. Энэ хэдэн үг хэвийн хүн чанар дахь Бурханы ажлыг төгсгөж, шүүлтийн эриний Бурханы ажлын хоёр дахь хэсгийг албан ёсоор эхлүүлдэг, энэ нь бурханлаг чанараар гүйцэтгэгддэг бөгөөд бүлэг хүмүүсийн төгсгөлийг зөгнөдөг. Одоо, Бурханы ардууд болсон үе нь шүүлтийн эриний хоёр дахь хэсэг байсан гэж Бурхан хүмүүст хэлээгүйг тайлбарлаваас зохистой. Харин, энэ хугацаан дахь Бурханы хүсэл, Бурханы хүрэхийг хүссэн зорилго, газар дээрх Бурханы ажлын эцсийн алхмын талаар хэлснийхээ дараа л Тэр, энэ бол шүүлтийн эриний хоёр дахь хэсэг юм гэж тайлбарласан. Үүнд бас Бурханы мэргэн ухаан байгааг хэлэх шаардлагагүй. Хэвтрийн орноосоо дөнгөж босох үедээ хүмүүс үхэх үү, үгүй юу, эсвэл өвчнөөсөө ангижирч чадах уу, үгүй юу гэдэгт л анхаардаг. Тэд жин нэмэх, эсвэл зөв хувцаслах эсэх талаараа огт анхаарал хандуулдаггүй. Тиймээс, өөрсдийгөө Бурханы ардуудын нэг гэдэгт хүмүүс бүрмөсөн итгэх үед л Бурхан Өөрийнхөө шаардлагуудын талаар алхам алхмаар ярьж, өнөөдөр ямар эрин болохыг хүмүүст хэлдэг. Яагаад гэвэл, хүмүүс эдгэснээсээ хойш хэдхэн өдрийн дараа л Бурханы удирдлагын алхмуудад анхаарлаа төвлөрүүлэх эрч хүчтэй болдог тул энэ нь тэдэнд хэлэхэд хамгийн тохиромжтой үе юм. Ойлгосныхоо дараа л хүмүүс задлан шинжилж эхэлдэг: Нэгэнт энэ нь шүүлтийн эриний хоёр дахь хэсэг тул Бурханы шаардлагууд улам хатуу чанд болж, би Бурханы ардуудын нэг болсон. Ийнхүү задлан шинжлэх нь зөв, ийм задлан шинжилгээ нь хүний хүрч чадах зүйл юм; тиймээс Бурхан ярихдаа энэ арга барилыг ашигладаг.

Хүмүүсийг бага зэрэг ойлгомогц Бурхан үг хэлэхийн тулд дахин нэгэнтээ сүнсний ертөнцөд ордог тул тэд дахин нэгэнтээ урхидуулдаг. Энэ цуврал асуултуудын үеэр хүн бүр толгойгоо маажин, будилаад Бурханы хүсэл хаана оршдогийг мэддэггүй, Бурханы аль асуултад хариулахаа мэддэггүй, түүнчлэн Бурханы асуултуудад хариулахдаа ямар хэл ашиглахаа мэддэггүй. Хүн инээх үү, эсвэл уйлах уу хэмээн гайхдаг. Хүмүүсийн хувьд эдгээр үг маш гүн гүнзгий нууцыг агуулж байгаа мэт санагддаг—гэвч бодит баримт яг эсрэгээрээ байдаг. Би энд чамд зориулан бага зэрэг тайлбар нэмсэн нь дээр байх—энэ нь уураг тархийг чинь амраах ба энэ нь энгийн зүйл, тийм ч их бодох шаардлагагүй гэдгийг чи мэдэрнэ. Үнэн хэрэгтээ, олон үг байдаг хэдий ч эдгээр асуултаар дамжуулан хүмүүсийн үнэнч занг олж авах гэсэн Бурханы цорын ганц зорилгыг тэдгээр нь агуулдаг. Гэхдээ үүнийг шууд хэлэх нь оновчтой биш тул Бурхан дахин нэгэнтээ асуулт ашигласан юм. Гэвч Түүний ярианы өнгө нэн зөөлөн, эхний хэсэгт байгаатай огт адилгүй. Хэдийгээр Бурханд байцаагдаж байгаа боловч ийм зөрүүтэй байдал нь

хүмүүст тайвшрал авчирдаг. Чи асуулт бүрийг нэг бүрчлэн уншсан нь дээр; эдгээр зүйл ихэвчлэн өнгөрсөнд болсон зүйлтэй хамаатай байдаг бус уу? Энэ цөөн хэдэн асуултад баялаг агуулга бий. Зарим нь хүмүүсийн сэтгэцийн тухай тодорхойлолт юм: “Та нар тэнгэрт байдаг амьдралтай адил газар дээрх амьдралыг эдлэхэд бэлэн байна уу?” Зарим нь Бурханы өмнө хүмүүсийн тавьсан “дайчны тангараг” юм: “Та нар өөрсдийгөө хонь адилаар Надаар нядлуулж, Надаар удирдуулж үнэхээр чадах уу?” Мөн зарим нь хүнд тавих Бурханы шаардлагууд юм: “Хэрвээ Би шууд яриагүй бол чи эргэн тойрныхоо бүх зүйлийг хаяж, өөрийгөө Надаар ашиглуулахыг зөвшөөрч чадах байсан уу? Энэ нь Миний шаарддаг бодитой байдал биш гэж үү? …” Тэдгээр нь бас хүнд хандах Бурханы ятгалга, тайтгаруулалтыг багтаадаг: “Гэсэн ч цаашид эргэлзээнд автахгүй байж, өөрсдийн оролтод санаачилгатай байж, Миний үгийн хамгийн гүнд хүрэхийг Би та нараас шаардаж байна. Энэ нь Миний үгийг буруу ойлгож, Миний утгыг ойлгохгүй байж, улмаар Миний захиргааны зарлигийг зөрчихөөс та нарыг сэргийлнэ.” Эцэст нь Бурхан хүний төлөөх итгэл найдварынхаа талаар ярьдаг: “Миний үгээс та нарын төлөө гэсэн Миний санаа зорилгыг та нар ухаарна гэж Би найдаж байна. Өөрсдийн хэтийн ирээдүйн талаар дахин бүү бод, мөн бүх зүйл дээр Бурханы зохион байгуулалтад захирагдана гэж Миний өмнө шийдвэр гаргасан мэт үйлд.” Сүүлчийн асуулт гүн гүнзгий утга учиртай. Энэ нь түлхэц өгч, хүмүүсийн зүрх сэтгэлд сэтгэгдэл төрүүлдэг бөгөөд чихэнд уясан хонх мэт тасралтгүй дуугаран, мартахын аргагүй байдаг…

Дээрх нь лавлагаа болгон ашиглахад чинь зориулсан цөөн хэдэн тайлбар үг юм.

5-Р БҮЛЭГ

Бурхан, тайлбарлахад хэцүү шаардлагыг нь хүмүүст тавих үед, мөн Түүний үг хүний зүрх сэтгэл рүү шууд цохиж, хүмүүс Түүнд эдлүүлэхийн тулд чин сэтгэлээ өргөн барих үед Бурхан хүмүүст тунгаан бодож, шийдвэр гаргаж, хэрэгжүүлэлтийн замыг эрж хайх боломж олгодог. Ийм маягаар Түүний ардууд болох бүх хүн дахин нэгэнтээ шийдвэртэйгээр нударга зангидан, бүхий л оршихуйгаа Бурханд өргөдөг. Магадгүй зарим нь өөрсдийгөө дайчлан шаргуу ажиллахаар бэлдэнгээ төлөвлөгөө зохиож, өдөр тутмын хуваарь гарган, Бурханы удирдлагын төлөвлөгөөнд алдрыг авчирч, үүнийг яаравчлан төгсгөхийн тулд хамаг хүч чадлаа зориулдаг байх. Хүмүүс ийм сэтгэхүй өвөрлөн, гэр орны ажлаа хийж, ярьж, ажилламгаа эдгээр зүйлийг оюун ухаандаа анхааралтай санаж байхад Бурхан: “Миний Сүнсний дуу хоолой бол бүхий л зан чанарын минь илэрхийлэл билээ. Та нар ойлгож байна уу?” хэмээн дахин ярьж эхэлсэн. Хүмүүс хэдий чинээ шийдэмгий байна, Бурханы хүслийг ухаарахаар тэдий чинээ цөхрөлтгүй тэмүүлэх бөгөөд Бурхан өөрсдөд нь шаардлага тавихыг тэдий чинээ чин сэтгэлээсээ хүсэн тэмүүлнэ. Иймээс Бурхан хүмүүст хүссэн зүйлийг нь өгч, удаан хугацаанд бэлэн байлгасан Өөрийн үгийг

тэдний оршихуйн хамгийн гүн хэсэгт оруулах энэ боломжийг ашиглана. Хэдий эдгээр үг бага зэрэг хатуу, ширүүн санагдаж болох ч хүмүүст тэдгээр нь харьцуулахын аргагүй аятайхан сонсогддог. Гэнэтхэн, тэдний зүрх сэтгэлд баяр хөөр төрж, тэнгэрт байсан мэт, эсвэл өөр ертөнц рүү—гаднын ертөнцийн хэрэг явдал хүмүүс рүү цаашид халдан дайрахгүй төсөөллийн жинхэнэ диваажин руу шилжсэн мэт байдаг. Хүмүүс урьдын зуршлаараа гаднаа ярьж, гаднаа үйлддэг тул зүй зохистой үндэс суурь тавьж чадахгүй байх тохиолдлоос зайлсхийхийн тулд хүмүүсийн зүрх сэтгэлдээ шаарддаг зүйл биелмэгц, түүнчлэн тэднийг дүрэлзсэн урам зоригтойгоор ажилдаа явахаар бэлтгэмэгц Бурхан Өөрийнхөө ярих аргыг тэдний сэтгэл санааны байдалд нийцүүлж, тэдний бүх хүсэл тэмүүлэл, зүрх сэтгэлдээ тээдэг шашны зан үйлийг юу ч үлдээлгүйгээр нэгтгэн дүгнэж няцаадаг. Бурханы хэлсэнчлэн: “Энд оршдог ач холбогдлыг та нар үнэхээр харсан уу?” Хүмүүс ямар нэгэн зүйлд шийдвэр гаргахаасаа өмнө юм уу дараа, Бурханы үйлдэл болон үгээс Бурханыг мэдэхэд ихээхэн ач холбогдол өгдөггүй, харин “Би Бурханы төлөө юу хийж чадах вэ? Тэр л гол асуудал!” хэмээн тунгаан бодсоор байдаг. Ийм учраас Бурхан: “Бас та нар Миний өмнө өөрсдийгөө Миний ардууд гэж нэрлэх зүрх зоригтой байдаг—та нарт ямар ч ичгүүр сонжуур байхгүй, эрүүл ухаан бүр ч байхгүй!” гэдэг. Бурхан эдгээр үгийг хэлмэгц хүмүүс даруй ухаараад, цахилгаан гүйдэлд цохиулсан мэт яаравчлан элгээ тэвэрч, Бурханы уур хилэнг хоёр дахь удаагаа өдөөхөөс ихэд айдаг. Үүн дээр нэмээд Бурхан бас: “Эрт орой хэзээ нэгэн цагт, та нар шиг хүмүүс Миний гэрээс таягдан хаягдана! Миний төлөө гэрчлэлд зогссон гэж бодоод Надад бүү ахарх!” гэж хэлсэн. Иймэрхүү үг сонсоод хүмүүс арслан харсан мэт бүр ч их айсан. Тэд зүрх сэтгэлдээ тун сайн мэддэг. Тэд арсланд идүүлэхийг хүсдэггүй, гэхдээ нөгөө талаар хаашаа зугтахаа ер мэддэггүй. Яг энэ хоромд, хүний зүрх сэтгэл доторх төлөвлөгөө ул мөргүйгээр, бүрмөсөн, бүхэлдээ арилдаг. Бурханы үгээр дамжуулан Би хүмүүсийн гутамшигт байдлын тал нэг бүрийг: коллежид элсэх шалгалтдаа унасан, эрхэм дээд туйлын зорилго, аз жаргалтай гэр бүл, гэрэл гэгээтэй ирээдүй гэх мэт нь 2000 он гэхэд Дөрвөн Шинэчлэлтийн хамтаар бүгд хоосон яриа төдий болж хувираад уран зөгнөлт кинон дахь төсөөллийн үзэгдлийг бүтээсэн хүн шиг толгой нь гудайсан, өөдгүй зан араншинг харж байгаа мэт санагддаг. Энэ нь идэвхгүй элементийг идэвхтэйгээр сольж, идэвхгүй байдалтай байгаа хүмүүсийг Бурханы оноож өгсөн байр сууринд зогсоохын төлөө байдаг. Гойд чухал зүйл бол хүмүүс энэ нэршлийг алдахаас гүнээ айдаг баримт юм; иймээс тэд албан тушаалаа орхихгүй зууралдаж, хэн нэгэн тэдгээрийг нь булаан авах вий гэж ихэд айж байдаг. Хүмүүсийн сэтгэл санааны байдал ийм байх үед Бурхан тэднийг идэвхгүй болно гэж санаа зовдоггүй тул шүүлтийн үгээ байцаалтын үг болгон өөрчилдөг. Тэрээр хүмүүст амьсгаа авах боломж олгоод зогсохгүй, мөн өмнө нь өөрсдөд нь байсан чин эрмэлзлийг одоо авч үзэн, тэдгээрийг хожмын лавлагаа болгон ангилах боломжийг тэдэнд олгодог: Тохиромжгүй зүйлийг өөрчилж болно. Ийм учраас Бурхан Өөрийн ажлыг хараахан

эхлээгүй байгаа—энэ нь асар золгүй явдлын дундах өчүүхэн жаахан сайн зол завшаан бөгөөд түүгээр ч үл барам энэ нь тэднийг ялладаггүй. Иймээс би Түүнд үнэнч байдлаа үргэлжлүүлэн өгье!

Дараа нь чи айдсаасаа болж Бурханы үгийг хойш тавих ёсгүй. Бурханд ямар нэгэн шинэ шаардлага байгаа эсэхийг хар. Мэдээж чи иймэрхүү шаардлагыг олж илрүүлнэ: “Энэ цагаас эхлээд чи бүх зүйл дээр хэрэгжүүлэлтийн бодит байдал руу орох ёстой; урьдынхтайгаа адилаар зүгээр дэмий чалчаад юунд ч хүрэхгүй.” Эндээс ч бас Бурханы мэргэн ухаан харагддаг. Бурхан Өөрийнхөө гэрчлэгчдийг үргэлж хамгаалж байсан бөгөөд өнгөрсөн үеийн үгийн бодит байдал төгсгөлдөө хүрэхэд “хэрэгжүүлэлтийн бодит байдлын” талаарх мэдлэгийг хэн ч ухан ойлгож чадахгүй. Энэ нь, Бурханы хэлсэн “Би Өөрөө ажлаа хийдэг” хэмээх үнэнийг батлахад хангалттай. Энэ нь бурханлаг чанараар ажиллахын жинхэнэ утга учиртай холбоотой, бас шинэ эхлэлийн цэгт хүрснийхээ дараа хүн төрөлхтөн Бурханы үгийн жинхэнэ утгыг ухан ойлгох чадваргүй хэвээр байдагтай ч холбоотой. Яагаад гэвэл, урьд нь асар олон хүн Бурханы үгэн дэх бодит байдалтай зууралддаг байсан, харин өнөөдөр тэдэнд хэрэгжүүлэлтийн бодит байдлын талаар ямар ч таамаг байдаггүй, эдгээр үгийн мөн чанарыг ойлгохгүйгээр өнгөц талуудыг нь л ойлгодог. Үүнээс ч чухал нь, өнөөдөр хаанчлалыг байгуулж байгаа учраас хэнд ч хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрдөггүй, харин Бурханы тушаалыг робот шиг дуулгавартай дагахыг л зөвшөөрдөг. Үүнийг сайн сана! Бурхан өнгөрсөн үеийг сөхөх болгондоо өнөөдрийн бодит нөхцөл байдлын талаар ярьж эхэлдэг; энэ бол өмнө нь болсон зүйл болон дараа нь болсон зүйлийн хооронд гайхалтай ялгааг бий болгодог ярианы хэлбэр бөгөөд ингэснээр илүү дээр үр дүнд хүрч, өнөө үеийг өнгөрсөн үетэй зэрэгцүүлэн тавиад, ийм маягаар энэ хоёрын хоорондох ялгааг хольж хутгахаас зайлсхийх боломжийг хүмүүст олгож чаддаг. Энэ бол Бурханы мэргэн ухааны нэг тал бөгөөд үүний зорилго нь ажлын үр дүнд хүрэхийн төлөө байдаг. Үүний дараа, хүмүүс Бурханы үгийг өдөр бүр идэж, уухаа хэзээ ч бүү мартаг гэсэндээ, мөн үүнээс ч чухал нь тэд өөрсдийгөө мэдэж авч, үүнийг өдөр бүр сурах ёстой хичээл хэмээн үзэг гэсэндээ Бурхан хүмүүсийн муу муухай байдлыг дахин нэгэнтээ илчилдэг.

Эдгээр үгийг хэлснийхээ дараа Бурхан анх зорьж байсан үр нөлөөндөө хүрсэн. Иймээс хүмүүс Түүнийг ойлгосон уу, үгүй юү гэдэгт цаашид анхаарал хандуулахгүйгээр Тэр цөөн хэдэн өгүүлбэрээр үүнийг хальт шүргэн өнгөрдөг, учир нь Сатаны ажил хүмүүстэй ямар ч хамаагүй—энэ талаар хүмүүст ямар ч таамаг байдаггүй. Одоо сүнсний ертөнцийг орхиод, Бурхан Өөрийнхөө шаардлагыг хүмүүст хэрхэн тавьдгийг цааш нь харцгаая: “Өөрийн орон байранд амрангаа Би анхааралтай ажигладаг: Газар дээрх бүх хүн өөрсдийнхөө хувь заяа, ирээдүйн төлөө үймэн бужигнаж, ‘дэлхийг тойрон аялж’, өөд уруугүй яаравчилдаг. Гэвч Миний хаанчлалыг байгуулахад зориулах эрч хүч ганцад нь ч байдаггүй, амьсгаа авах хэмжээний хүчин чармайлт ч байдаггүй.” Эдгээр зугаатай яриаг хүмүүстэй солилцсоныхоо дараа Бурхан тэдэнд мөн л анхаарал хандуулдаггүй, харин Сүнсний өнцгөөс үргэлжлүүлэн

ярьж, эдгээр үгээрээ хүн төрөлхтний амьдралын ерөнхий нөхцөл байдлыг бүхэлд нь илчилдэг. Хүний амьдрал ямар ч утгагүй гэдэг нь “дэлхийг тойрон аялж” болон “өөд уруугүй яаравчилдаг” гэдгээс харахад тодорхой юм. Бурханы бүхнийг чадагч аврал байгаагүй бол Хятадын эзэн хааны удмын уруудан мөхөж буй өнөр гэр бүлд төрсөн хүмүүс насан туршдаа бүр ч хий дэмий амьдрах магадлалтай ба энэ дэлхийд ирснээс Үхэгсдийн орон юм уу тамд унах нь тэдний хувьд дээр байх байсан юм. Агуу улаан лууны эрхшээл дор тэд өөрийн мэдэлгүй Бурханд халдсан, тиймээс аяндаа, өөрийн мэдэлгүй Бурханы гэсгээлт дор унасан юм. Энэ шалтгааны улмаас, Бурхан хүмүүст өөрсдийг нь илүү тодорхой мэдүүлэхийн тулд “аварсан” ба “ач тус мэддэггүй” гэдгийг аваад, хооронд нь харьцуулан тавьж, үүнээс Өөрийн авралын нигүүлслийг товойлгогчийг бий болгодог. Энэ нь бүр ч үр ашигтай үр дүнд хүрдэг бус уу? Мэдээж, Бурханы айлдваруудын агуулгаас хүмүүс зэмлэсэн элементийг, авралын болон уриалан дуудсан элементийг, бас бага зэргийн уйтгар гунигийн битүүхэн дохиог мэдэрч чадна гэдгийг Би заавал тодорхой хэлээд байх шаардлагагүй. Эдгээр үгийг уншаад хүмүүс өөрийн мэдэлгүй гуниглаж эхэлдэг ба өөрийн эрхгүй нулимс урсгадаг… Гэхдээ Бурхан цөөн хэдэн уй гашуутай мэдрэмжээс болж хязгаарлагдахгүй, мөн бүхий л хүн төрөлхтний завхралаас болоод Өөрийн ардуудыг сахилгажуулж, тэдэнд шаардлага тавих ажлаа орхихгүй. Үүнээс үүдэн Түүний сэдвүүд өнөөдрийн нөхцөл байдал зэргийг даруй хөндөж, түүнчлэн Өөрийн төлөвлөгөөг үргэлжлүүлэн явуулахын тулд захиргааны зарлигийнхаа сүр жавхланг хүмүүст тунхагладаг. Ийм учраас боломжит бүх хурдаараа үүнийг дагаж, төмрийг халуун байхад нь давтаад Бурхан энэхүү шийдвэрлэх мөчид энэ цагийн үндсэн хуулийг буюу хүмүүс Бурханы хүслийг ойлгохын тулд заалт бүрийг нь хянуур анхааралтай унших ёстой үндсэн хуулийг гаргадаг. Одоо энэ талаар цааш ярих хэрэггүй; хүмүүс зүгээр л илүү анхааралтай унших ёстой.

Өнөөдөр энд байгаа энэ бүлэг хүмүүс та нар бол Бурханы үгийг үнэхээр харж чадах хүмүүс юм. Тэгсэн ч гэсэн Бурханыг мэдэхдээ өнөөдрийн хүмүүс өнгөрсөн эрин үеүдэд байсан ямар ч хүнээс хавьгүй хол хоцорсон. Энэ хэдэн мянган жилийн туршид Сатан хүмүүст хэчнээн их хичээл чармайлт гаргасан нь, мөн түүнчлэн хүн төрөлхтнийг завхруулсан хэмжээ нь асар их болохоор Бурхан хэдий олон үг хэлсэн ч хүмүүс Бурханыг ойлгодоггүй, бас мэддэг ч үгүй, харин өндийн босож, Түүнийг илт эсэргүүцдэг нь эндээс харахад хангалттай тодорхой байна. Иймээс Бурхан өнгөрсөн эрин үеийн хүмүүсийг өнөөдрийн хүмүүстэй үргэлж харьцуулан тавиад мэдрэмжгүй, мулгуу сүүлийнх нь хүмүүст бодитой лавлагаа өгдөг. Хүмүүст Бурханы талаар ямар ч мэдлэг байхгүй учраас, мөн тэдэнд Түүнд итгэх жинхэнэ итгэл дутмаг учраас Бурхан хүмүүсийг чадвар болон эрүүл ухаанаар дутмаг гэж үзсэн; тиймээс Тэр хүмүүст ахин дахин хүлээцтэй хандаж, аврал хайрласан юм. Сүнсний ертөнц дэх тулаан ийм байдлаар явагддаг: Хүн төрөлхтнийг тодорхой хэмжээнд завхруулж, дэлхий ертөнцийг бузар булай, ёрын муу болгосноор хүмүүсийг намаг балчигт хутгаж, Бурханы төлөвлөгөөг нураах нь Сатаны хий

хоосон найдлага билээ. Гэхдээ Бурханы төлөвлөгөө нь бүх хүнийг Бурханыг мэддэг хүмүүс болгохын төлөө байдаггүй, харин бүх хүнийг төлөөлөх нэг хэсгийг сонгон авч, үлдсэнийг нь хогийн цэгт хаягдах үйлдвэрлэлийн хаягдал, гологдол бараа болгон орхих явдал юм. Тиймээс хэдийгээр Сатаны үзэл бодлын үүднээс цөөн хэдэн хүнийг эзэмших нь Бурханы төлөвлөгөөг нураах гайхалтай боломж шиг санагддаг ч Сатан мэтийн тийм маанаг амьтан Бурханы санаа зорилгыг мэдэж яахан чадах билээ? Ийм учраас Бурхан: “Энэ дэлхий ертөнцийг харахаас зайлсхийхийн тулд Би нүүрээ халхалсан” хэмээн аль эрт хэлсэн юм. Бид энэ талаар бага зэрэг мэддэг бөгөөд Бурхан хүмүүсээс ямар нэгэн зүйл хийх чадвартай байхыг шаарддаггүй; харин Түүний хийдэг зүйл гайхамшигтай агаад хэмжээлшгүй гэдгийг танин мэдэж, Түүнийг зүрх сэтгэлдээ хүндлэхийг шаарддаг. Хэрвээ хүмүүсийн төсөөлдөг шигээр Бурхан нөхцөл байдлыг нь харгалзан үзэхгүйгээр тэднийг гэсгээдэг байсан бол бүхий л дэлхий ертөнц аль хэдийн мөхчихсөн байх байлаа. Энэ нь яг Сатаны урхинд орсонтой адил байх бус уу? Иймээс Бурхан оюун санаандаа байгаа үр дүнд хүрэхийн тулд Өөрийн үгийг ашигладаг төдий боловч хааяа бодит баримтууд байдаг. “Хэрвээ Би эрдэм чадал, эрүүл ухаан, гүн ойлголт дутуу дулимгийг чинь харгалзан үзээгүй бол та нар бүгдээрээ Миний гэсгээлтийн дунд мөхөж, амьдралаас арчигдах байлаа. Гэсэн хэдий ч, газар дээрх Миний ажил дуусах хүртэл Би хүн төрөлхтөнд хүлээцтэй ханддаг хэвээр байна” хэмээх Түүний үгийн нэг тохиолдол энэ биш гэж үү?

6-Р БҮЛЭГ

Хүмүүс Бурханы айлдваруудыг унших үедээ цочирдон гайхдаг бөгөөд хүний хийж чадахааргүй асар их үйл хэргийг Бурхан сүнсний ертөнцөд хийсэн, үүнийг Бурхан Өөрөө л биечлэн гүйцэлдүүлэх ёстой гэж боддог. Иймээс Бурхан хүн төрөлхтөнд хандан хүлээцтэй үгээ дахин нэгэнтээ хэлсэн юм. Тэгэхэд тэд: “Бурхан бол өршөөл, хайр энэрлийн Бурхан биш, гагцхүү хүнийг цохин унагадаг Бурхан. Тэр яагаад бидэнд хүлээцтэй хандаж байгаа юм бэ? Бурхан арга барилаа дахин нэгэнтээ сольсон юм гэж үү?” хэмээн зүрх сэтгэлдээ зөрчилддөг. Ийм үзэл, ийм бодол сэтгэлд нь төрөх үед тэд үүний эсрэг бүх чадлаараа тэмцэхээр оролддог. Гэвч Бурханы ажил хэсэг хугацаанд явагдсаны дараа Ариун Сүнс чуулганы дотор асар их ажил хийж, хүн бүр чиг үүргээ биелүүлж эхлэн, бүх хүн Бурханы арга барилд ордог, учир нь Бурханы хэлдэг, хийдэг зүйлээс хэн ч, ямар ч өө сэв олж харж чаддаггүй. Бурханы дараагийн алхам яг юу байх тухайд гэвэл үүнийг хэн ч, өчүүхэн ч таамаглаж чадахгүй. Бурханы хэлсэнчлэн: “Тэнгэрийн дор амьдарч байгаа бүх хүнээс хэн Миний гарт байдаггүй вэ? Хэн Миний удирдамжийн дагуу үйлддэггүй вэ?” Гэхдээ Би та нарт жаахан зөвлөгөө өгье: Өөрсдийнхөө тодорхой мэддэггүй хэрэг явдал дээр хэн ч юм хэлж, хийж болохгүй. Би урам зоригийг чинь

мохоох гэж биш, харин үйлдэлдээ Бурханы удирдамжийг дагах боломжийг чамд олгохын тулд үүнийг хэлдэг. “Өө сэвийн” талаар дурдсанаас минь болоод чи яавч хулчийж, эргэлзэх ёсгүй; Бурханы үгэнд анхаарал хандуулахыг чамд сануулах нь Миний гол зорилго юм. “Сүнсний доторх хэрэг явдалд, чи нарийн мэдрэмжтэй байх хэрэгтэй; Миний үгийг хичээнгүйлэн анхаарах ёстой. Миний Сүнс ба Миний бие махбодыг, Миний үг ба Миний бие махбодыг хуваагдашгүй нэгэн бүхэл мэт харах тэрхүү төлөв байдлыг зорих хэрэгтэй, ингэснээр бүх хүн Миний өмнө Намайг сэтгэл хангалуун байлгаж чадна” хэмээх Бурханы үгийг унших үедээ хүмүүс дахин балмагдсан. Өчигдөр тэд анхааруулгын үг, Бурханы хүлээцтэй байдлын тухай үг уншиж байсан—гэтэл өнөөдөр Бурхан гэнэтхэн сүнсний хэрэг явдлын тухай ярьж байна. Яг юу болоод байна аа? Яагаад Бурхан үг хэлэх арга барилаа өөрчилсөөр байдаг юм бэ? Яагаад энэ бүхнийг хуваагдашгүй нэгэн бүхэл гэж үзэх ёстой вэ? Бурханы үг бодитой биш байж таарах уу? Бурханы үгийг сайтар уншсаны дараа, Бурханы махбод болон Сүнсийг салгах үед махбод нь махан биеийн шинж тэмдэгтэй бие болдог буюу хүмүүсийн хэлдгээр алхаж буй цогцос болдог гэдгийг олж мэдсэн. Бурханы махбод болсон бие нь Сүнснээс ирдэг: Тэр бол Сүнсний биелэл, махбод болсон Үг билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө махбодод амьдардаг. Бурханы Сүнсийг Түүний оршихуйгаас салгахын ноцтой байдал энэ юм. Үүний үр дүнд, хэдийгээр Түүнийг хүн гэж нэрлэдэг ч Тэрээр хүн төрөлхтнийх биш. Түүнд хүний ямар ч шинж тэмдэг байдаггүй, Тэр бол Бурханы Өөрийгөө хувцасласан оршихуй, Бурханы зөвшөөрдөг оршихуй юм. Бурханы үг Бурханы Сүнсийг агуулдаг, Бурханы үг махбодоор шууд илчлэгддэг, түүнчлэн Бурхан махбодод амьдардаг, илүү бодитой Бурхан гэдгийг энэ нь харуулж, улмаар Бурханы оршин тогтнолыг нотолж, Бурханд хандах хүн төрөлхтний тэрслүү байдлын эрин үеийг төгсгөдөг. Бурханыг мэдэх замыг хүмүүст хэлснийхээ дараа Бурхан сэдвээ дахин нэгэнтээ өөрчилж, асуудлын нөгөө талыг барьж авдаг.

“Би орчлон ертөнцийг Өөрийн хөлөөр туулж, харцаа хаяа хязгаарт нь бэлчээж, хүний туршлагын чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай амтыг амтлан бүх хүний дунд алхсан.” Хэдий энгийн боловч эдгээр үгийг хүн төрөлхтөн амархан ойлгодоггүй. Сэдэв өөрчлөгдсөн ч мөн чанартаа бол хэвээрээ байгаа: Энэ нь мөн л хүмүүст бие махбодтой болсон Бурханыг мэдүүлдэг. Яагаад Бурхан, хүний туршлагын чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай амтыг амтлана гэж хэлдэг вэ? Яагаад Тэр бүх хүний дунд алхсан гэж хэлдэг вэ? Бурхан бол Сүнс, гэхдээ Тэр бас бие махбодтой оршихуй. Бие махбодтой оршихуйн хязгаарлалтад баригддаггүй Сүнс орчлон ертөнцийг хөлөөрөө туулж, харцаа хаяа хязгаарт нь бэлчээж чаддаг ба Бурханы Сүнс бүх сансар огторгуйг дүүргэж, нэг туйлаас нөгөө туйлыг нь хүртэл газар дэлхийг хамардаг, Бурханы гараар зохицуулагддаггүй юу ч үгүй, Түүний мөр гараагүй ямар ч газар байдаггүй гэдгийг харуулдаг. Хэдийгээр Сүнс махбод болж, хүн болон төрсөн ч Сүнсний оршин тогтнол нь хүний бүх хэрэгцээг няцаадаггүй; Бурханы оршихуй хэвийн байдлаар хооллож, хувцаслаж, унтаж, оршин сууж,

хүмүүсийн хийх ёстой зүйлийг хэвийн байдлаар хийдэг. Гэхдээ дотоод мөн чанар нь өөр болохоор Тэр бусдын ярьдаг “хүн”-тэй адилгүй. Хэдийгээр Тэр хүн төрөлхтний дунд зовдог ч энэ зовлонгоос болоод Сүнсийг орхидоггүй. Хэдийгээр Тэр ерөөгдсөн ч энэ ерөөлөөс болоод Сүнсийг мартдаггүй. Сүнс, оршихуй хоёр чимээгүй зохицон ажилладаг. Сүнс, оршихуй хоёрыг салгаж болохгүй, Тэд хэзээ ч салж байгаагүй, учир нь оршихуй бол Сүнсний биелэл бөгөөд Сүнснээс буюу хэлбэр дүрстэй Сүнснээс ирдэг. Тиймээс махбод дахь Сүнсний хувьд ер бусын байх боломжгүй; өөрөөр хэлбэл, Сүнс ер бусын зүйл хийж чадахгүй буюу Сүнс бие махбодыг орхин явж чадахгүй. Хэрвээ Тэр махан биеэс салаад явсан бол Бурхан бие махбодтой болохын бүх утга учир алдагдах байлаа. Сүнс бие махбодоор бүрэн илэрхийлэгдэх үед л хүн бодитой Бурханыг Өөрийг нь мэдэж чадна, зөвхөн тэр үед л Бурханы хүсэл биелнэ. Бие махбод болон Сүнсийг хүмүүст тус тусад нь танилцуулсныхаа дараа л Бурхан хүний харалган, дуулгаваргүй байдлыг зааж үзүүлсэн: “Гэвч үнэндээ хүн Намайг хэзээ ч таниагүй, Намайг хаа сайгүй явахад ч анзаараагүй.” Нэг талаар Бурхан, Өөрийгөө махбодод сэмхэн нууж, хүмүүст харуулахын тулд ямар нэгэн ер бусын зүйл хэзээ ч хийж байгаагүй гэж хэлж байна; нөгөө талаар Тэр, хүн Өөрийг нь мэддэггүй гэж гомдоллодог. Энд ямар ч зөрчилдөөн байхгүй. Үнэндээ үүнийг дэлгэрэнгүй харвал, Бурхан энэ хоёр талаас Өөрийнхөө зорилгод хүрдгийг харахад хэцүү биш. Хэрвээ Бурхан ер бусын тэмдэг, гайхамшиг үзүүлдэг байсан бол агуу ажил хийх шаардлагагүй байх байв. Тэр зүгээр л Өөрийнхөө амаар хүмүүсийг үхтэл нь харааж, тэд тэр даруй насан эцэслэж, улмаар бүх хүн үнэмших байлаа—гэхдээ энэ нь махбод болсон Бурханы зорилгыг биелүүлдэггүй. Хэрвээ Бурхан үнэхээр ийнхүү үйлдсэн бол хүмүүс Түүний оршин тогтнолд ухамсартайгаар итгэж хэзээ ч чадахгүй байх байлаа. Тэд үнэхээр итгэж чадахгүй байх байсан бөгөөд түүнчлэн диаволыг Бурхан хэмээн андуурах байв. Үүнээс ч чухал нь, хүмүүс Бурханы зан чанарыг хэзээ ч мэдэж чадахгүй байх байв—энэ нь махбод дахь Бурханы оршихуйн утга учрын нэг тал биш гэж үү? Хэрвээ хүмүүс Бурханыг мэдэх чадваргүй байсан бол тэрхүү тодорхойгүй Бурхан, тэрхүү ер бусын Бурхан хүмүүсийн дунд үүрд нөлөөлөх байлаа. Ингэвэл хүмүүс өөрсдийнхөө үзэлд эзэмдүүлэх байсан бус уу? Илүү тодорхой хэлэх юм бол диавол Сатан үүнд нөлөөлж байх байсан биш үү? “Яагаад Би эрх мэдлээ буцаан авсан гэж хэлдэг вэ? Яагаад Би, бие махбодтой болох нь маш их утга учиртай гэж хэлдэг вэ?” Бурхан махбод болох мөч нь Өөрийн эрх мэдлийг буцаан авдаг үе юм, мөн Түүний бурханлаг чанар шууд үйлдэхээр гарч ирдэг үе юм. Бүх хүн бодитой Бурханыг аажмаар мэдэж авч, улмаар зүрх сэтгэлд нь буй Сатаны орон зайг бүрмөсөн арилгаад, өөрсдийнхөө зүрх сэтгэл дэх илүү гүн гүнзгий орон зайг Бурханд өгдөг. Урьд нь хүмүүс Бурханыг оюун ухаандаа Сатаны дүрээр харж, гарт баригддаггүй, нүдэнд үзэгддэггүй Бурхан гэж хардаг байсан; гэсэн ч энэхүү Бурхан нь оршин байдгаар зогсохгүй, төрөл бүрийн тэмдэг, гайхамшиг үзүүлэн, чөтгөрт эзэмдүүлсэн хүмүүсийн үзэшгүй муухай байдал гэх мэтийн олон нууцыг илчлэх чадвартай гэж

тэд итгэсэн юм. Энэ нь, хүмүүсийн оюун ухаан дахь Бурхан бол Бурханы дүр ч биш, харин Бурханаас өөр зүйлийн дүр юм гэдгийг хангалттай нотолдог. Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлийн 0.1 хувийг эзлэхийг хүсдэг гэж хэлсэн. Энэ нь хүмүүсээс шаарддаг Түүний хамгийн өндөр стандарт билээ. Өнгөц талаас нь цааш харвал эдгээр үгэнд бас бодитой тал байдаг. Хэрвээ үүнийг ингэж тайлбарлаагүй бол өөрсдөд нь Бурханы тавьдаг шаардлага хэтэрхий доогуур агаад Бурхан өөрсдийнх нь талаар хэтэрхий бага ойлгодог гэж хүмүүс бодох байв. Энэ нь хүний сэтгэхүй биш гэж үү?

Дээр дурдсан зүйл болон доор буй Петрийн жишээг нийлүүлснээр Петр Бурханыг үнэхээр хэнээс ч илүү сайн мэддэг байсныг олж мэдэж болно, учир нь тэрээр тодорхойгүй Бурханаас нүүр буруулж, бодитой Бурханы талаарх мэдлэгийг эрэлхийлсэн билээ. Түүний эцэг эх Бурханыг эсэргүүцдэг чөтгөрүүд байсан гэдгийг яагаад онцгойлон дурдсан бэ? Петр өөрийн зүрх сэтгэл дэх Бурханыг эрэлхийлж байгаагүйг энэ нь нотолдог. Түүний эцэг эх тодорхойгүй Бурханы төлөөлөгч байсан; Бурхан тэднийг дурдсаны утга учир энэ юм. Ихэнх хүмүүс энэ баримтыг тийм ч их анхаардаггүй. Харин тэд Петрийн залбиралд анхаарлаа төвлөрүүлдэг. Зарим хүний хувьд Петрийн залбирал үргэлж аманд нь, байнга оюун санаанд нь байдаг ч тодорхойгүй Бурханыг Петрийн мэдлэгтэй хэзээ ч харьцуулан үзэж байгаагүй. Яагаад Петр эцэг эхийнхээ эсрэг хандаж, Бурханыг мэдэхээр эрж хайсан юм бэ? Яагаад Петр бүтэлгүйтсэн хүмүүсээс сургамж авахаар өөрийгөө зоригжуулсан бэ? Яагаад тэрээр эрин үеүдийн туршид Бурханыг хайрлаж байсан бүх хүний итгэл болон хайрыг өөрийн болгосон бэ? Бүх эерэг зүйл Бурханаас эхтэй ба Сатаны ямар ч боловсруулалтаар дамжилгүй Түүнээс шууд ирдэг гэдгийг Петр мэдэж авсан юм. Түүний мэдэж авсан Бурхан бол ер бусын Бурхан биш, харин бодитой Бурхан байсан гэдгийг энэ нь харуулдаг. Петр эрин үеүдийн туршид Бурханыг хайрлаж байсан бүх хүний итгэл болон хайрыг өөрийн болгоход анхаарсан гэж яагаад хэлдэг вэ? Хүмүүс эрин үеүдийн туршид бүтэлгүйтэж байсан нь үндсэндээ тэдэнд зөвхөн итгэл, хайр байсан боловч бодитой Бурханыг мэдэж чадаагүйгээс нь болсон гэдгийг харж болно. Үүний үр дүнд тэдний итгэл тодорхойгүй хэвээр үлдсэн юм. Яагаад Бурхан, Иов Бурханыг мэддэг байсан гэж хэлэлгүйгээр Иовын итгэлийг олон удаа дурддаг вэ, яагаад Бурхан Иовыг Петртэй эн тэнцэхгүй гэж хэлдэг вэ? “Би Таны тухай чихээрээ сонссон: харин одоо нүдээрээ Таныг харж байна” хэмээх Иовын үг, түүнд итгэл л байсан боловч ямар ч мэдлэг байгаагүй гэдгийг харуулдаг. “Товойлгогч болон үйлчлэх эцэг эхийнх нь сөрөг жишээ байснаар энэ нь түүнийг Миний хайр, энэрлийг илүү амархан таних боломжтой болгосон” хэмээх үг ихэнх хүмүүст үргэлж асар олон асуулт төрүүлдэг: Бурханыг мэдэхийн тулд Петрт яагаад товойлгогч хэрэгтэй байсан юм бол? Яагаад тэр Бурханыг шууд мэдэж чадаагүй юм бол? Яагаад тэр Бурханы өршөөл, хайр энэрлийг л мэддэг, мөн Бурхан өөр юу ч ярьдаггүй байсан юм бол? Тодорхойгүй Бурханы бодит бус байдлыг танин мэдсэний дараа л бодитой Бурханы талаарх мэдлэгийг эрж хайх боломжтой;

хүмүүсийн зүрх сэтгэлээс тодорхойгүй Бурханыг арилгах нь эдгээр үгийн зорилго билээ. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл хэрвээ хүмүүс Бурханы жинхэнэ нүүр царайг үргэлж мэддэг байсан бол Сатаны үйл хэргийг ялган таньж чадахгүй байх байв, учир нь “хүн уул давах хүртлээ газрын өндрийг анзаардаггүй” хэмээх түгээмэл хэллэг Бурхан эдгээр үгийг хэлсний утга учрыг харуулдаг. Бурхан Өөрийн татсан жишээгээр үнэнийг хүмүүст илүү гүн ойлгуулахыг хүсдэг учраас өршөөл болон хайр энэрлийг зориуд онцолж, Петрийн амьдарч байсан эрин үе нь Нигүүлслийн эрин үе байсан гэдгийг нотолдог. Өөр өнцгөөс харвал энэ нь, хүнийг хорлож, завхруулдаг диаволын жигшүүрт төрхийг илүү их илчилж, Бурханы өршөөл, хайр энэрлийг бүр ч хурцаар сөргүүлэн тавьдаг.

Бурхан бас Петрийн шалгалтуудын тухай баримтуудыг тоймлож, тэдгээрийн бодит нөхцөл байдлыг дүрсэлж, улмаар Бурханд зөвхөн өршөөл, хайр энэрэл байгаад зогсохгүй, мөн сүр жавхлан, уур хилэн байдаг, амар тайван амьдардаг хүмүүс заавал Бурханы ерөөл дунд амьдарч байх албагүй гэдгийг хүмүүст үзүүлдэг. Шалгалтуудын дараах Петрийн туршлагын талаар хүмүүст хэлж байгаа нь “Бид Бурханы гараас сайныг хүлээн аваад мууг хүлээн авахгүй юу?” хэмээх Иовын үгийн үнэн зөв байдлыг бүр ч их нотолдог. Тиймээс энэ нь, Бурханы талаарх Петрийн мэдлэг үнэндээ урьд өмнө байгаагүй түвшинд буюу урьдын эрин үеийн хүмүүсийн хэзээ ч хүрч байгаагүй түвшинд хүрсэн гэдгийг харуулдаг бөгөөд энэ нь бас эрин үеүдийн туршид Бурханыг хайрлаж байсан бүх хүний итгэл болон хайрыг өөрийн болгож, урьд нь бүтэлгүйтсэн хүмүүсийн сургамжийг ашиглан өөрийгөө зоригжуулсных нь үр дүн байлаа. Ийм учраас, Бурханы талаарх жинхэнэ мэдлэгт хүрсэн бүх хүнийг “үр жимс” гэж нэрлэдэг бөгөөд үүнд Петр багтдаг. Бурханд хандсан Петрийн залбирал нь шалгалтуудын үед түүнд байсан Бурханы талаарх жинхэнэ мэдлэгийг харуулдаг. Гэвч нэг жаахан дутагдал нь тэрээр Бурханы хүслийг бүрэн ухан ойлгох чадваргүй байсан, ийм учраас Петрийн олж авсан Бурханы тухай мэдлэгт үндэслээд Бурхан “хүний зүрх сэтгэлийн ердөө 0.1 хувийг эзэмдэх” шаардлага тавьсан. Бурханыг хамгийн сайн мэддэг байсан хүн болох Петр хүртэл Бурханы хүслийг үнэн зөв ухаарах чадваргүй байсан нь хүмүүст Бурханыг мэдэх эрхтэн байхгүй гэдгийг харуулдаг, учир нь Сатан тэднийг маш их завхруулсан; энэ нь хүний мөн чанарыг бүх хүнд мэдэгддэг. Хүмүүст Бурханыг мэдэх эрхтэн байдаггүй ба Сатан тэдэнд бүрэн дүүрэн нэвчсэн байдаг гэх энэ хоёр урьдач нөхцөл нь Бурханы агуу хүч чадлыг товойлгон харуулдаг, учир нь Бурхан үгтэй л ажилладаг ба өөр ямар ч зүйл хийдэггүй, тийнхүү хүмүүсийн зүрх сэтгэлд тодорхой байр суурь эзэлдэг. Яагаад хүмүүс Бурханы хүслийг хангахын тулд 0.1 хувьд хүрэх хэрэгтэй байдаг вэ? Бурхан хүнд энэ эрхтэнийг бүтээгээгүй гэдгээр үүнийг тайлбарлаж болно. Хэрвээ энэ эрхтэн байхгүй байхад хүн Бурханы талаарх зуун хувийн мэдлэгт хүрсэн бол Бурханы хөдөлгөөн болгон хүнд тов тодорхой болох байсан бөгөөд төрөлхийн уг чанараасаа үүдэн хүмүүс даруй Бурханы эсрэг тэрсэлж, Түүнийг илт эсэргүүцэн босох байсан, Сатан ингэж л унасан юм. Иймээс,

Бурхан хүмүүсийг хэзээ ч доогуур үнэлдэггүй, учир нь Тэр хүнийг аль хэдийн нэгд нэггүй задлан шинжилж, тэдний талаарх бүх юмыг тов тодорхой мэддэг, бүр цусанд нь хэр их ус холилдсоныг хүртэл яг таг мэддэг. Тэгвэл хүний уг чанар Түүнд хэчнээн илүү тодорхой байх билээ? Бурхан хэзээ ч алдаа гаргадаггүй ба айлдваруудынхаа үгийг туйлын нарийн сонгодог. Тиймээс Петр Бурханы хүслийг үнэн зөв ухаараагүй болон Бурханы талаар хамгийн сайн мэддэг байсны хооронд ямар ч зөрчилдөөн байдаггүй; түүнчлэн энэ хоёр нь хоорондоо ямар ч холбоогүй. Хүмүүсийн анхаарлыг Петрт хандуулахын тулд Бурхан түүнийг жишээ болгон дурдаагүй. Яагаад Иов шиг хүн Бурханыг мэдэж чадаагүй, харин Петр чадсан юм бэ? Хүн үүнд хүрэх чадвартай гэж Бурхан хэлдэг атлаа энэ нь Бурханы агуу хүч чадлаас болдог гэж яагаад хэлдэг юм бэ? Хүмүүс үнэхээр угаасаа сайн гэж үү? Хүмүүсийн хувьд үүнийг мэдэхэд амаргүй байдаг; хэрвээ Би энэ талаар яриагүй бол үүний дотоод утга учрыг хэн ч ухаарахгүй. Эдгээр үгийн зорилго нь хүмүүст ухаарал өгөхийн төлөө байдаг бөгөөд ингэснээр тэд Бурхантай хамтран ажиллах итгэлтэй байж чадна. Тэр үед л Бурхан хүний хамтын ажиллагааны хамтаар ажиллаж чадна. Энэ нь сүнсний ертөнц дэх бодит нөхцөл байдал, хүний огтхон ч ухан мэдэж чадахааргүй зүйл. Хүмүүсийн зүрх сэтгэлээс Сатаны эзэлдэг байр суурийг таягдан хаяж, тэр байрыг Бурханд өгөх нь Сатаны дайралтыг няцаана гэсэн үг бөгөөд ингэсэн үед л Христ газар дээр бууж ирсэн гэж хэлж болно, тэгсэн үед л газар дэлхий дээрх хаанчлалууд Христийн хаанчлал болсон гэж хэлж болно.

Петр хэдэн мянган жилийн туршид үлгэр дуурайл, жишээ байсаар ирсэн гэдгийг энд дурдсан нь тэр бол үлгэр дуурайл, жишээ байсан гэж зүгээр л хэлэхийн төлөө байгаагүй; эдгээр үг нь сүнсний ертөнцөд явагдаж байсан тулааны тусгал юм. Энэ бүх хугацаанд Сатан хүнд ажиллаж, түүнийг залгин, тэгснээрээ дэлхий ертөнцийг устгаж, Өөрийн гэрчлэлийг алдахад Бурханыг хүргэхээр хий дэмий найдсаар ирсэн. Гэхдээ Бурхан: “Би эхлээд үлгэр дуурайлыг бүтээнэ, ингэснээр Би хүний зүрх сэтгэл дотор хамгийн өчүүхэн байр суурийг эзэлж болох юм. Энэ үе шатанд хүмүүс Миний таалалд ч нийцдэггүй, Намайг ч бүрэн мэддэггүй; гэхдээ Миний агуу хүч чадлаас үүдэн хүмүүс Надад бүрэн захирагдаж, Миний эсрэг тэрслэхээ больж чадна, Би Сатаныг ялахын тулд энэ үлгэр жишээг ашиглана. Өөрөөр хэлбэл, Би хүмүүсийг мэдэлдээ байлгаж байсан Сатаны бүх хүчийг дарахын тулд хүний зүрх сэтгэлд Өөрийн эзэлдэг 0.1 хувийг ашиглана” гэж хэлсэн юм. Иймээс өнөөдөр Бурхан бүх хүн төрөлхтний даган дуурайж, хэрэгжүүлэх үлгэр загвар болгохын тулд Петрийг жишээ болгон дурдсан. Үүнийг эхний хэсэгтэй нийлүүлбэл, сүнсний ертөнц дэх бодит нөхцөл байдлын талаар Бурханы хэлсэн зүйлийн үнэн мөнийг харж болно: “Юмс одоо урьдынх шигээ байхаа больсон: Би бүтээлийн эхлэлээс хойш хүний хэзээ ч үзээгүй зүйлсийг хийж, эрин үеүдийн туршид хүний хэзээ ч сонсож байгаагүй үгийг хэлэх гэж байна, учир нь Би бүх хүн төрөлхтнөөс махбод дахь Намайг мэддэг болооч гэж хүсдэг.” Бурхан Өөрийн үгийг өнөөдөр хэрэгжүүлж эхэлсэн гэдгийг үүнээс харж болно. Хүмүүс гадна талд юу тохиолдож байгааг л

харж чадна, харин сүнсний ертөнцөд яг юу болж байгааг харж чадахгүй тул Бурхан шууд ийнхүү хэлсэн: “Энэ бол Миний удирдлагын алхмууд бөгөөд энэ талаарх өчүүхэн төдий ч таамаг хүмүүст байдаггүй. Би энэ талаар илэн далангүй ярьсан ч хүний оюун санаа нь мунгинасаар байдаг болохоор түүнд нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй. Хүний адгийн дорд байдал үүнд оршдог, тийм биз?” Эдгээр үгэн дотор үг бий: Дээр дүрсэлсэнчлэн тулаан сүнсний ертөнцөд болж байгаа гэдгийг тэдгээр нь тайлбарладаг.

Петрийн түүхийг товч дүрсэлсний дараа Бурханы хүсэл бүрэн биелээгүй тул Бурхан Петрийн хэрэг явдлуудтай холбогдуулан хүнд дараах шаардлагыг тавьсан юм: “Орчлон ертөнц болон хязгааргүй уудам огторгуй даяар, тэнгэр, газар дахь бүх зүйл, газар дээрх тоо томшгүй олон зүйл, тэнгэр дэх үй олон зүйл нэг бүрчлэн Миний ажлын сүүлийн үе шатны төлөө бүх хүч чадлаа зориулж байна. Та нар Сатаны хүчээр ийш тийш жолоодуулж, хөндлөнгийн ажиглагчид болж үлдэхийг хүсэхгүй байлгүй дээ?” Петрийн мэдлэгийн тухай уншсаны дараа хүмүүс гүн гүнзгий гэгээрүүлэгддэг ба бүр их үр нөлөө үзүүлэхийн тулд Бурхан хүмүүст садар самуун, эрээ цээргүй байж, Бурханыг мэддэггүй байхын үр дагаврыг харуулдаг; түүнчлэн сүнсний ертөнц дэх тулааны үеэр яг юу тохиолдож байгааг дахин нэг удаа, асар их нарийвчлалтайгаар хүмүүст хэлдэг. Ийм маягаар л хүмүүс Сатанд олзлогдохгүйн тулд илүү сонор сэрэмжтэй болж чадна. Түүнчлэн, хэрвээ хүмүүс энэ удаа унах л юм бол энэ удаа Бурханаар аврууллахгүй гэдгийг энэ нь тодорхой болгодог. Хамтад нь авч үзвэл эдгээр анхааруулга нь, Бурханы үгийн талаарх хүмүүсийн сэтгэгдлийг гүнзгийрүүлдэг ба Бурханы өршөөлийг улам их нандигнаж, Бурханы анхааруулгын үгийг илүү их эрхэмлэхэд хүмүүсийг хүргэдэг, ингэснээр хүн төрөлхтнийг аврах Бурханы зорилгыг үнэхээр биелүүлдэг.

ПЕТРИЙН АМЬДРАЛЫН ТУХАЙД

Петр хүн төрөлхтөнд зориулсан Бурханы үлгэр дуурайл, бүгдийн мэддэг нэр цуутан байсан билээ. Яагаад тийм онцлох юмгүй хүнийг Бурхан үлгэр жишээ болгон өргөж, удаах үеийнхэн нь шагшин магтсан юм бэ? Петр Бурханыг гэх хайраа илэрхийлж, Бурханыг хайрлахаар сэтгэл шулуудсантай энэ нь салшгүй холбоотой гэдгийг хэлэх илүүц биз. Харин Бурханыг хайрлах Петрийн зүрх сэтгэл яаж илэрсэн, түүний амьдралын туршлага үнэндээ ямар байсан тухайд бол, бид тэр үеийн ёс заншлыг дахин харж, тухайн үеийн Петрийг ажиглахын тулд Нигүүлслийн эрин үед эргэн очих ёстой юм.

Петр иудейн эгэл жирийн тариачин айлд төржээ. Эцэг эх нь гэр бүлийнхнээ бүгдийг нь тариалангаар тэжээдэг байсан бөгөөд Петр дөрвөн дүүтэй, айлын ууган хүүхэд байлаа. Энэ мэдээж манай түүхийн гол хэсэг биш; Петр бидний гол дүр билээ. Петрийг таван настай байхад эцэг эх нь бичиг үсэг зааж эхэлжээ. Тухайн

үед иудей хүмүүс нэлээд өргөн мэдлэгтэй, мөн хөдөө аж ахуй, аж үйлдвэр, худалдаа гэх мэт салбарууд нь гойд хөгжсөн байв. Нийгмийн орчноосоо үүдэн Петрийн эцэг эх хоёр хоёулаа дээд боловсрол эзэмшсэн байсан юм. Хөдөөгийн хүмүүс хэдий ч тэд өндөр боловсролтой, өнөөгийн их сургуулийн дундаж оюутантай харьцуулж болохоор байлаа. Мэдээж Петр нийгмийн тийм таатай нөхцөлд төрсөн нь ерөөлтэй хэрэг байв. Ухаалаг, юм сурахдаа хурдан тэрээр шинэ санааг дор нь өөрийн болгодог байлаа. Сурч боловсорч эхэлснийхээ дараа Петр хичээлийн үеэр аливааг маш хурдан ойлгодог байжээ. Эцэг эх нь ийм сэргэлэн хүүтэй гэдгээрээ бахархаж, нийгэмд онцгойрч, нэг төрлийн албан тушаалд орж чадна гэж найдсандаа Петрт сургуульд явах боломж олгохын тулд чадах чинээгээрээ хичээжээ. Петр өөрийн мэдэлгүй Бурханыг сонирхдог болсон байснаас үүдэн арван дөрвөн настайдаа ахлах сургуульд өөрийн сурч байсан эртний Грекийн соёлын тухай сургалтын хөтөлбөрөөс, нэн ялангуяа эртний Грекийн түүхэн дэх зохиомол хүмүүс, хийсвэр үйл явдлуудаас залхсан юм. Идэр залуу насандаа дөнгөж хөл тавьсан Петр тэр үеэс хойш хүний амьдрал болон уудам ертөнцийн талаар илүү ихийг олж мэдэхээр оролдож эхэлсэн байна. Хүмүүс бүгд өөрсдийгөө хуурсан байдлаар амьдарч, эд хөрөнгө, нэр алдрын төлөөх тэмцлээр өөрсдийн амьдралыг сүйрүүлэн, бүгдээрээ утга учиргүй амьдрал дунд аж төрж байгааг Петр тодорхой харсан тул эцэг эхийнхээ үүрсэн зовлонг хариул гэж мөс чанар нь түүнийг албадсангүй. Петрийн ойлголт гол төлөв аж төрж байсан нийгмийн орчноос нь улбаатай байсан юм. Хүмүүс эрдэм мэдлэгтэй болох тусам хүн хоорондын харилцаа, дотоод ертөнц нь улам ээдрээтэй болж, улмаар тэд улам бүр хий хоосон дунд оршдог. Эдгээр нөхцөлд Петр ихэвчлэн шашны хүмүүс дээр өргөн хүрээтэй айлчлал хийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байлаа. Хүний ертөнц дэх тайлбарлагдашгүй бүхнийг шашин л тайлбарлаж чадаж магадгүй гэх бүдэг бадаг мэдрэмж зүрх сэтгэлд нь төрсөн тул үе үе ойролцоох синагог руу явж, үйлчлэлд оролцдог байв. Эцэг эх нь энэ талаар мэдээгүй бөгөөд үргэлж сайн ааш араншинтай, сурлага өндөртэй байсан Петр төд удалгүй сургуульд явахыг үзэн ядаж эхэлжээ. Эцэг эхийнхээ хяналт дор тэрээр ахлах сургуулиа арай ядан дүүргэсэн юм. Тэгээд эрдэм мэдлэгийн далайгаас сэлж гараад гүнзгий амьсгаа авсан аж. Тэр цагаас хойш Петрийг дахин хэн ч сурган хүмүүжүүлж, хязгаарлаагүй билээ.

Петр сургуулиа дүүргэсний дараа элдэв янзын ном уншиж эхэлсэн боловч арван долоон настайдаа уудам ертөнцийн талаар нэг их туршлагагүй хэвээр байлаа. Сургууль төгсөөд газар тариалан эрхлэн амин зуулгаа залгуулахын хажуугаар ном уншиж, шашны үйлчлэлд оролцоход чадах чинээгээрээ их цаг гаргадаг байв. Түүнд их найдлага тавьж явсан эцэг эх нь “тэрслүү хүүгээсээ” болоод Тэнгэрийг үргэлж хараадаг байсан ч зөв шударга байдлаар өлсөж, цангаж байсан Петрт энэ нь ч бас саад хийж чадсангүй. Петр туршлагадаа цөөнгүй тооны бүтэлгүйтэл амссан ч ирмүүн зүрх сэтгэлтэй байсан тэрээр борооны дараах өвс шиг л өсжээ. Төд удалгүй түүнд шашны ертөнцийн зарим дээгүүр зиндааныхантай

уулзах “аз завшаан” тохиосон бөгөөд Петрийн хүсэл тэмүүлэл маш хүчтэй байсан учраас тэдэнтэй улам ойр ойрхон холбогдож эхлэн, эцэстээ бараг бүхий л цаг хугацаагаа тэдэнтэй хамт өнгөрөөх болсон аж. Энэ хүмүүсийн дийлэнх нь амаараа итгэдэг болохоос итгэлдээ зүрх сэтгэлээ өгөөгүй гэдгийг сэтгэл хангалуун аз жаргалд умбаж явсан Петр гэнэтхэн ухаарсан юм. Шулуун шударга, гэнэн сэтгэлтэй явсан Петр ийм цохилтыг яахан тэсвэрлэж чадах билээ? Өөрийнх нь холбоо барьж байсан бараг бүх хүн бол хүний арьс нөмөрсөн араатан, хүн дүртэй адгуус гэдгийг тэр ухаарсан юм. Тухайн үед Петр маш гэнэн байсан тул хэд хэдэн удаа тэднээс зүрх сэтгэлээсээ гуйжээ. Гэхдээ шашны атгаг санаат, зальхай энэ хүмүүс дүрэлзсэн сэтгэлт энэ залуугийн гуйлтыг яалаа гэж сонсох билээ? Тэр үед л Петр хүний амьдралын жинхэнэ хий хоосон байдлыг мэдэрсэн юм: Амьдралын тайзан дээрх эхний алхамдаа Петр бүтэлгүйтсэн байлаа… Нэг жилийн дараа тэрээр синагогоос нүүн одоод, бие даан амьдарч эхэлжээ.

Энэ бүтэлгүйтэл 18 настай Петрийг хавьгүй илүү төлөвшүүлж, хашир болгосон юм. Идэр залуу насны гэнэн байдлын ямар ч ул мөр түүнд үлдсэнгүй. Залуу насны цайлган, болхи байдлыг Петрийн амссан бүтэлгүйтэл энэрэлгүйгээр бөхөөж, тэрээр загасчны амьдрал эхлүүлэв. Дараа нь завин дээрээ Петрийн номлохыг хүмүүс сонсож байгаа харагддаг болжээ. Петр загасчилж амин зуулгаа залгуулахдаа явсан газар бүрдээ мэдээ түгээдэг байсан бөгөөд ярьдаг зүйл нь эгэл ардын сэтгэлийн чавхдасыг хөндөж, үнэнч байдал нь тэд бүгдийн сэтгэлийг гүнээ хөдөлгөдөг байсан тул түүний номлолыг сонссон бүх хүн номлолд нь сэтгэл татагддаг байлаа. Зүрх сэтгэлээсээ хайрладаг Бурханаа бүх хэрэг явдал дээр сэтгэл хангалуун байлгаж, бусдад зүрх сэтгэлээсээ ханд, тэнгэр газар, бүх зүйлийн Захирагчийг дууд, мөс чанараа үл хайхран ичгүүртэй зүйл бүү хий гэж хүмүүст ихэвчлэн сургадаг байжээ… Петрийн номлолыг сонссоны дараа хүмүүсийн сэтгэл үргэлж гүнээ хөдөлдөг байв; тэд бүгд Петрээс урам авч, үе үе сэтгэл хөдлөн нулимс унагадаг байлаа. Тухайн үед, ядуу зүдүү, эгэл жирийн дагалдагчид нь бүгд Петрийг асар их биширдэг байсан бөгөөд тэр үеийн нийгмийн байдлаас үүдэн тун цөөн тоотой байсан аж. Түүнчлэн Петрийг тухайн үеийн нийгэм дэх шашны хүмүүс хяхан хавчдаг байлаа. Энэ бүхнээс үүдэн Петр хоёр жилийн турш нэг газраас нөгөөд нүүдэллэж, ганцаардмал амьдралаар амьдарч байсан юм. Энэ хоёр жилийн ер бусын туршлагынхаа үеэр Петр урьд нь мэддэггүй байсан зүйлсийнхээ талаар ихээхэн мэдлэгтэй болж, асар ихийг сурч авснаар 14 настай үеийнхээсээ танигдахааргүй болж, тэр үеийнхээсээ тэс өөр санагдах болжээ. Тэр хоёр жилд Петр янз бүрийн хүмүүстэй уулзаж, нийгмийн талаар элдэв янзын үнэнийг олж харсны үр дүнд шашны ертөнцийн бүх төрлийн зан үйлээс аажмаар ангижирч эхэлсэн юм. Түүнчлэн тухайн үеийн Ариун Сүнсний ажлын хөгжил Петрт гүнээ нөлөөлсөн билээ; тэгэхэд Петр Есүстэй хараахан уулзаагүй байсан ч Есүс ажиллаад олон жил болж байсан тул тухайн үеийн Ариун Сүнсний ажил Петрийн ажилд мөн нөлөөлжээ. Энэ шалтгааны улмаас, Петр номлож байхдаа өмнөх

үеийнх нь ариун хүмүүст хэзээ ч байгаагүй олон зүйлийг олж авсан юм. Мэдээж хэрэг тухайн үед Петр Есүсийн талаар багахан мэддэг байсан боловч Түүнтэй нүүр тулан уулзах боломж хараахан гараагүй байлаа. Петр Ариун Сүнснээс төрсөн тэрхүү тэнгэрлэг хүнтэй уулзана гэж л найдаж, хүсэн хүлээдэг байсан билээ.

Нэгэн орой бүрэнхий болж байхад Петр завин дээрээ (тухайн үед Галил нуур гэгддэг байсан нуурын эргийн ойролцоо) загасчилж байлаа. Гартаа загасны уурга барьсан ч ухаан санаандаа өөр юм бодож байв. Жаргаж буй нар усан мандлыг уудам цусан далай мэтээр гэрэлтүүлжээ. Гэрэл Петрийн залуу атлаа тайван, дөлгөөн царайд тусахуйд тэрээр гүн бодолд автсан харагдаж байлаа. Тэр мөчид сэвшээ салхи үлээж, Петр амьдралынхаа ганцаардмал байдлыг гэнэт мэдэрсэн бөгөөд энэ нь түүнд тэр даруй зэврүүн хүйтэн мэдрэмж төрүүлэв. Нуурын давлагаа гэрэлд гялтганахад Петр загасчлах ямар ч санаа бодолгүй байгаа нь тодорхой байлаа. Бодолд автан байх зуураа тэрээр, “Иудейн Ионагийн хүү Симон оо, амьдралын чинь өдөр хоногууд ганцаардмал юм. Чи намайг дагах уу?” гэж араас нь нэг хүн хэлэхийг гэнэт сонслоо. Цочсондоо Петр барьж байсан загасны уургаа шууд унагасан нь тэр даруй нуурын ёроол руу живжээ. Петр яаран эргэж хартал завин дээр нь нэг хүн зогсож байгаа харагдав. Тэр хүнийг хөлөөс нь толгой хүртэл харахад мөрөө хүртэл унжсан үс нь нарны гэрэлд үл ялиг алтран шаргалтах агаад саарал хувцас өмссөн, дунд хэрийн өндөртэй, хөлөөс толгой хүртлээ иудей хүний өмсгөлөөр хувцасласан байх ажээ. Бүдгэрэх гэрэлд тэр хүний саарал хувцас үл ялиг харлан харагдаж, царай нь ялимгүй туяарах мэт байлаа. Петр Есүстэй уулзах гэж олон удаа хичээсэн боловч хэзээ ч амжилт олоогүй байсан юм. Тухайн мөчид Петр тэр хүнийг зүрх сэтгэлийнх нь ариун нэгэн байж таарна гэдэгт сэтгэлийнхээ гүнээс итгэсэн тул загасчны завин дээр нүүрээрээ газар унан мөргөж, “Тэнгэрийн хаанчлалын сайн мэдээ номлохоор ирсэн Эзэн Та юм гэж үү? Би Таны туршлагыг сонссон ч Таныг хэзээ ч харж байсангүй. Дагая гэж хүссэн боловч Таныг олж чадсангүй” гэв. Тэр үед Есүс завины бүхээгт очоод тайван сууж байлаа. “Босоод Миний хажууд суу!” гэж Тэр хэлэв. Тэгээд “Намайг үнэхээр хайрладаг хүмүүсийг эрж хайхаар Би энд ирлээ. Би ялангуяа тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээхээр ирсэн юм. Надтай нэг санаатай хүмүүсийг эрж хайхын тулд газар нутаг даяар аялна. Чи бэлэн үү?” гэлээ. “Тэнгэрлэг Эцэгийн илгээсэн нэгнийг би дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг би хүлээн зөвшөөрөх ёстой. Тэнгэрлэг Эцэгийг би хайрладаг болохоор Таныг дагахад бэлэн биш байж яахан болох билээ?” гэж Петр хариулжээ. Хэдийгээр Петрийн үг шашны үзлээр дүүрэн байсан ч Есүс сэтгэл ханамжтайгаар инээмсэглэн, толгой дохив. Тэр мөчид Петрийг хайрлах эцгийн сэтгэл Түүний дотор төржээ.

Петр Есүсийг олон жилийн турш дагаад, бусад хүнд байдаггүй нэлээд их зүйлийг Түүнээс олж харсан юм. Өөрийг нь нэг жил дагасны дараа Есүс Петрийг арван хоёр шавийнхаа дундаас сонгожээ. (Мэдээж Есүс үүнийгээ ил хэлээгүй бөгөөд бусад нь энэ тухай огт мэдээгүй юм.) Амьдрал дээр Петр Есүсийн хийдэг

бүх зүйлээр өөрийгөө хэмждэг байв. Хамгийн гол нь, Есүсийн номлосон мэдээ Петрийн зүрх сэтгэлд сийлэгдсэн байсан юм. Петр Есүст туйлын үнэнч, тууштай байсан бөгөөд Түүний эсрэг ямар ч гомдол огт хэлээгүй юм. Иймээс Есүсийн явсан газар бүрд Петр итгэмжит нөхөр нь болсон билээ. Петр Есүсийн сургаал, зөөлөн үгийг ажиглаж, юугаар хооллож, юу өмсөж, хаана байрлаж, яаж аялдгийг нь ажигладаг байв. Тэгээд бүх талаар Есүсийг даган дуурайдаг байлаа. Петр хэзээ ч өөрийгөө зөвтгөлгүй, хоцрогдсон бүхнийг хаяж, үг яриа, үйл хэргийнхээ аль алинд Есүсийн үлгэр жишээг дагадаг байсан юм. Тэнгэр газар, бүх зүйл Төгс Хүчитийн гарт байдаг, ийм учраас өөрт нь хувийн сонголт гэж үгүй гэдгийг Петр тэр үед мэдэрчээ. Түүнчлэн Есүс юу болох бүхнийг Петр уусган авч, үлгэр жишээ болгон ашигладаг байлаа. Есүс хийдэг зүйлдээ Өөрийгөө зөвтгөдөггүй байсан; Өөрийнхөө талаар онгирохын оронд хүмүүсийн сэтгэлийг хайраар хөдөлгөдөг байсныг Есүсийн амьдрал харуулдаг. Есүс юу болохыг янз бүрийн зүйл харуулсан бөгөөд үүнээс үүдэн Петр Түүний бүх зүйлийг даган дуурайсан юм. Есүсийн хайр татам байдлыг Петр өөрийн туршлагаар улам бүр мэдрээд, “Би орчлон ертөнц даяар Төгс Хүчитийг хайсан, бас тэнгэр газар, бүх зүйлийн гайхамшгийг харсан тул Төгс Хүчитийн хайр татам байдлыг гүнээ мэдэрлээ. Гэхдээ миний зүрх сэтгэлд хэзээ ч жинхэнэ хайр байгаагүй, бас би Төгс Хүчитийн хайр татам байдлыг хоёр нүдээрээ хэзээ ч хараагүй байсан. Өнөөдөр, Төгс Хүчитийн нүд намайг ивээн харж, эцэст нь би Бурханы хайр татам байдлыг мэдэрлээ. Хүн төрөлхтөн Бурханыг зүгээр л бүх зүйлийг бүтээсэн болохоор нь хайрладаг юм биш гэдгийг эцэст нь би олж мэдлээ; өдөр тутмын амьдралдаа би Түүний энгүй хайр татам байдлыг оллоо. Үүнийг яг одоо харж болох зүйлээр хязгаарлаж яахан болох билээ?” гэх мэт зүйл хэлсэн юм. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Петрт ч бас хайр татам зүйл нэлээд их гарч ирсэн юм. Тэрээр Есүст маш дуулгавартай болж, мэдээж бас нэлээд хэдэн бүтэлгүйтэл амсжээ. Есүс янз бүрийн газарт номлол хийхээр Петрийг авч явахад Петр үргэлж даруу байж, Есүсийн номлолыг сонсдог байлаа. Есүсийг олон жил дагасан гээд Петр хэзээ ч биеэ тоогоогүй юм. Есүс ажлаа дуусгахын тулд цовдлогдох гэж ирсэн хэмээн хэлэхийг сонсоод Петр үе үе зүрх сэтгэлдээ энэлэн шаналж, нууцаар цурхиран уйлдаг байв. Гэсэн хэдий ч тэр “золгүй” өдөр эцэст нь ирсэн билээ. Есүсийг баривчлагдсаны дараа Петр загасчны завиндаа ганцаараа цурхиран уйлж, үүний төлөө олон залбирал хэлжээ. Гэвч энэ нь Эцэг Бурханы хүсэл бөгөөд хэн ч үүнийг өөрчилж чадахгүй гэдгийг зүрх сэтгэлдээ мэдэж байлаа. Петр гагцхүү хайраасаа л үүдэн энэлэн шаналж, нүдэндээ нулимс цийлгэнүүлсээр байсан юм. Энэ мэдээж хүний сул тал байв. Иймээс Есүс загалмайд цовдлогдоно гэдгийг олж мэдээд Петр: “Та явсныхаа дараа бидний дунд байж, биднийг харж хандахаар эргэн ирэх үү? Бид Тантай уулзаж чаддаг хэвээр байх уу?” гэж Есүсээс асуусан билээ. Хэдийгээр эдгээр үг маш гэнэн, хүний үзлээр дүүрэн байсан ч Петрийн зовлонгийн гашууныг Есүс мэдэж байсан тул хайраараа Петрийн сул талыг бодолцон үзээд: “Петр, Би чамайг хайрласан. Тэрийг чи мэдэх үү? Хэдийгээр хэлж

байгаа зүйл чинь цаанаа ямар ч шалтгаангүй ч Би эргэн амилсныхаа дараа хүмүүст 40 хоногийн турш харагдана гэдгийг Эцэг амласан. Миний Сүнс та бүхний дээр байнга нигүүлсэл хайрлана гэдэгт чи итгэхгүй байна уу?" хэмээжээ. Петр үүгээр бага зэрэг тайтгарсан ч нэг юм дутагдаж байгаа мэт санагдсаар байсан тул Есүс дахин амилсныхаа дараа эхний удаад түүнд ил тод үзэгдсэн юм. Гэхдээ Петрийг үзэлтэйгээ зууралдсаар байхаас сэргийлэхийн тулд Есүс Өөрт нь зориулж бэлдсэн элбэг дэлбэг хоолноос татгалзаад нүд ирмэхийн зуурт алга болжээ. Тэр мөчөөс хойш Петр эцэст нь Эзэн Есүсийг илүү гүн гүнзгий ойлгох болж, бүр ч их хайрласан юм. Есүс дахин амилсныхаа дараа Петрт үе үе харагддаг байлаа. Дөчин өдөр нь дуусаж, тэнгэр өөд гарсныхаа дараа Тэрээр Петрт дахиад гурван удаа үзэгджээ. Илрэлт бүр нь яг Ариун Сүнсний ажил гүйцэлдэж, шинэ ажил эхлэх гэж байхад тохиосон билээ.

Петр насан туршдаа загасчилж амин зуулгаа залгуулсан ч хамгийн гол нь тэрээр номлох гэж амьдарсан юм. Тэгээд хожмын жилүүддээ Петрийн нэг, хоёрдугаар захидлаас гадна тухайн үеийн Филаделфийн чуулганд хэд хэдэн захиа бичжээ. Петр тэр үеийн хүмүүсийн сэтгэлийг гүнээ хөдөлгөсөн юм. Өөрийн амжилт ололтыг ашиглан хүмүүст сургаал айлдахын оронд тэднийг амийн зохих хангалтаар хангадаг байлаа. Явахынхаа өмнө Есүсийн сургасан сургаалыг хэзээ ч мартаагүй тэрээр насан туршдаа тэдгээрээс урам зориг авчээ. Есүсийг дагаж байхдаа Петр Эзэний хайрыг үхлээрээ хариулж, бүх зүйл дээр Түүний үлгэр жишээг дагахаар сэтгэл шулуудсан юм. Есүс үүнийг нь зөвшөөрсөн тул Петрийг 53 настай байхад (Есүсийг явснаас хойш 20 гаруй жилийн дараа) хүсэл эрмэлзлийг нь биелүүлэхэд туслахаар Есүс түүнд үзэгджээ. Удаах долоон жилийн амьдралаа Петр өөрийгөө мэдэж авахад зориулсан юм. Энэ долоон жилийн төгсгөлд нэгэн өдөр тэрээр уруу харан цовдлогдож, улмаар ер бусын амьдралаа эцэслэсэн билээ.

8-Р БҮЛЭГ

Бурханыг Сүнсний өнцгөөс ярих үед Түүний ярианы өнгө бүх хүн төрөлхтөн рүү чиглэдэг. Бурханыг хүний өнцгөөс ярих үед Түүний ярианы өнгө Түүний Сүнсний удирдамжийг дагадаг бүх хүн рүү чиглэдэг. Бурхан гуравдагч хүний өнцгөөс (хүмүүсийн хэлдгээр бол ажиглагчийн үзэл бодлын үүднээс) ярих үедээ Өөрийн үгийг хүмүүст шууд харуулдаг, ингэснээр тэд Түүнийг тайлбарлагч гэж үзэх бөгөөд хүмүүсийн мэддэггүй, ухан ойлгож чаддаггүй энгүй их зүйл Түүний амнаас гардаг мэт санагддаг. Тийм биш гэж үү? Бурхан Өөрийн үгийг Сүнсний өнцгөөс ярих үед бүх хүн гайхширдаг. "Намайг гэсэн хүмүүсийн хайр өчүүхэн бөгөөд Надад итгэх итгэл нь ч бас өрөвдмөөр жаахан. Хэрвээ Би Өөрийн үгийн гол цохилтыг хүмүүсийн сул тал руу чиглүүлээгүй бол тэд бардамнаж, дэгсдүүлэн, газар дэлхийн хэрэг явдлын талаар анддаггүй, бүгдийг мэддэг мэтээр номчирхож, хэрээс хэтэрсэн

онолуудыг зохиох байлаа.” Эдгээр үг хүний байгаа байдлыг болон хүмүүсийн зүрх сэтгэл дэх Бурханы байр суурийг илчлээд зогсохгүй, бас хүн төрөлхтний бүхий л амьдралыг ил болгодог. Хүн бүр өөрсдийгөө ер бусын хэмээн боддог мөртөө “Бурхан” гэдэг үг байдаг гэдгийг ч мэддэггүй. Тиймээс тэд хэрээс хэтэрсэн онолуудыг зохиож зүрхэлдэг. Гэхдээ, ингэж “хэрээс хэтэрсэн онолуудыг зохиох” нь хүмүүс ойлгохуйц байдлаар “ярих” явдал биш. Харин хүмүүсийг Сатан завхруулсан гэсэн үг юм. Тэдний хийдэг бүхэн, үйлдэл болгон Бурханы эсрэг байж, Түүнийг шууд эсэргүүцдэг ба тэдний үйлдлийн мөн чанар Сатанаас ирдэг, Бурханы эсрэг байдаг, бие даах зорилготой бөгөөд Бурханы хүслийг сөрдөг. Ийм учраас Бурхан, хүмүүс бүгдээрээ хэрээс хэтэрсэн онолуудыг зохиодог гэж хэлдэг. Өөрийнх нь үгийн гол цохилт хүний сул тал руу чиглэдэг гэж Бурхан яагаад хэлдэг вэ? Учир нь Бурханы санаа зорилгын дагуу, хэрвээ Тэр хүний зүрх сэтгэлийн гүнд нуугдсан зүйлсийг илчлээгүй бол ямар ч хүн захирагдахгүй байх байсан; тиймээс хүмүүс өөрсдийгөө ойлгохгүй, Бурханыг хүндлэн үзэхгүй байх байлаа. Өөрөөр хэлбэл, хэрвээ хүмүүсийн санаа зорилгыг ил болгохгүй бол тэд юу ч хийж зүрхэлнэ—магадгүй бүр Тэнгэр лүү, эсвэл Бурхан руу ч хараалаа чиглүүлнэ. Эдгээр нь хүний сул тал. Тиймээс Бурхан: “Миний санаа зорилготой нийцдэг, Надаар ашиглуулахад тохирдог хүмүүсийг зогсолтгүй хайхдаа Би орчлон ертөнцийн бүх булан тохойгоор аялдаг” гэж хэлсэн юм. Энэхүү мэдэгдэл нь хаанчлалын ёслолын буудлага албан ёсоор цангинах тухай сүүлд хэлсэн зүйлийн хамтаар Бурханы Сүнс газар дээр шинэ ажил эрхэлдэг гэдгийг харуулдаг; зүгээр л хүмүүс үүнийг нүдээрээ харж чадахгүй байгаа юм. Сүнс газар дээр шинэ ажил хийж байгаа гэж хэлсэн тул бүхий л орчлон ертөнцөд ч бас томоохон өөрчлөлт гардаг: Бурханы хөвгүүд, ардууд бие махбодтой болсон Бурханы гэрчлэлийг хүлээн авч эхэлдгээр үл барам, шашин, урсгал болгон, нийгмийн давхарга, газар нутаг болгон янз бүрийн түвшинд үүнийг бас хүлээн авдаг. Энэ нь сүнсний ертөнц дэх орчлон ертөнцийн асар их хөгжил хөдөлгөөн юм. Энэ нь бүхий л шашны ертөнцийг үндсээр нь ганхуулдаг бөгөөд өмнө нь дурдаж байсан “газар хөдлөлтийн” утга учрын нэгээхэн хэсэг билээ. Дараа нь тэнгэрэлчүүд албан ёсоор ажлаа эхлүүлж, Израилийн ард түмэн дахин хэзээ ч тэнүүчлэхгүйгээр төрөлх нутагтаа буцан очсон ба энд багтсан бүх хүн хариулгыг хүлээн авдаг. Үүнтэй харьцуулахад, египетчүүд Миний авралын цар хүрээнээс салж эхэлдэг; өөрөөр хэлбэл, тэд Миний гэсгээлтийг хүлээн авч эхэлдэг (гэхдээ энэ нь хараахан албан ёсоор эхлээгүй байгаа). Иймээс дэлхий ертөнцөд ийм хэдэн томоохон өөрчлөлт нэгэн зэрэг гарч байгаа энэ үе нь бас хаанчлалын ёслолын буудлага албан ёсоор тасхийдэг үе, хүмүүсийн “долоо дахин эрчимжсэн Сүнс ажиллаж эхлэх цаг” хэмээн нэрлэдэг үе юм. Бурхан сэргээлтийн ажил хийх болгонд, эдгээр үе шатанд (эсвэл эдгээр шилжилтийн үед) хэн ч Ариун Сүнсний ажлыг мэдэрч чаддаггүй. Тиймээс “хүмүүс итгэл найдвараа алдах үед” хэмээх Бурханы үг үнэн байдаг. Түүнчлэн эдгээр шилжилтийн үе шат болгонд хүмүүс итгэл найдвараа алдах үед, эсвэл энэ урсгал буруу гэж тэдэнд санагдах үед Бурхан

шинээр эхэлж, Өөрийн ажлын дараагийн алхмыг хийдэг. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Бурхан Өөрийн ажлыг сэргээж, ийм маягаар Өөрийн ажилладаг арга барилыг өөрчилсөн. Хэдийгээр ихэнх хүмүүс янз бүрийн түвшинд энэ ажлын зарим нэг талыг ухаарч чаддаг ч биеийн хэмжээ нь хэтэрхий жаахан учраас эцэстээ тэд ямартай ч усны ширүүн урсгалаар угаагдан арилдаг; тэд Бурханы ажлын алхмуудыг ухаарч чаддаггүй тул таягдан хаягддаг. Гэхдээ Бурхан бас хүмүүсийг ингэж ариусгадаг бөгөөд энэ нь хүмүүсийн хуучин үзэлд хандах Бурханы шүүлт билээ. Хүмүүст хэдий чинээ их суурь байна, Бурханы талаарх шашны үзэл нь төдий чинээ их байдаг ба тэдний хувьд үүнийг хойш тавихад хэцүү байдаг; тэд хуучин зүйлстэй үргэлж зууралддаг бөгөөд тэдний хувьд шинэ гэрлийг хүлээн авахад хэцүү байдаг. Нөгөө талаар хэрвээ хүн зогсож байгаа л бол зогсох зарим нэг суурь түүнд байх ёстой, гэхдээ ихэнх хүмүүс өөрсдийн үзлийг хойш тавихдаа асуудалтай байдаг. Ялангуяа өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы талаарх тэдний үзэл ийм байдаг бөгөөд харваас илэрхий юм.

Өнөөдрийн үгэнд Бурхан үзэгдлийн талаар ихээхэн ярьсан ба дэлгэрүүлж ярих шаардлагагүй. Бурхан үндсэндээ, чуулганыг байгуулах явдал хэрхэн хаанчлалыг байгуулах суурь болдог тухай ярьсан. Илүү тодорхой хэлэх юм бол, чуулганыг байгуулж байх үеийн гол зорилго нь, хүмүүс бие махбодтой болсон Бурханыг нүдээрээ хараагүй байсан ч зүрх сэтгэлээр нь, үгээр нь тэднийг үнэмшүүлэхийн төлөө байсан юм. Хэдий тэд зүрх сэтгэлдээ итгэл өвөрлөж байсан ч бие махбодтой болсон Бурханыг мэдээгүй, учир нь тухайн үе шатанд Тэрээр хүнээс ялгагдах юмгүй байлаа. Хаанчлалын эрин үед бүх хүн зүрх сэтгэл, үг яриа, нүдээрээ итгэл үнэмшлээ харуулах ёстой. Бүх хүн зүрх сэтгэл, үг яриа, нүдээрээ итгэл үнэмшлээ харуулахын тулд албан шахалтаар биш, ердийн нэг итгэл бишрэлээр ч биш, харин өөрсдийнх нь зүрх сэтгэл, амнаас гардаг мэдлэгтэйгээр, махбодод амьдарч байгаа Бурханыг нүдээрээ харж мэдэх ёстой гэдгийг энэ нь хангалттай харуулдаг. Тиймээс бүтээн байгуулалтын энэ үе шатанд ямар ч тулаан, ямар ч аллага байдаггүй. Харин Бурханы үгээр хүмүүсийг гэгээрүүлдэг бөгөөд үүгээр дамжуулан тэд эрэлхийлж, судлан шинжилж, улмаар бие махбодтой болсон Бурханыг дотоод ухамсраараа мэдэж авч чадна. Иймээс Бурханы хувьд ажлын энэ үе шат хавьгүй илүү амархан, бүхнийг жамаар нь явуулдаг ба хүмүүсийн эсрэг явдаггүй. Эцэстээ энэ нь, Бурханыг аяндаа мэдэж авахад хүмүүсийг хүргэнэ, тиймээс бүү санаа зов, бүү түгш. Бурханы хэлсэн “Сүнсний ертөнцийн тулаан Миний бүх ардын дунд шууд ил болдог” гэдэг нь хүмүүс зөв замд орж, Бурханыг мэдэж эхлэх үед хүн бүр дотроо Сатанд уруу татагддагаар зогсохгүй, чуулганд ч гэсэн Сатанд уруу татагдах болно гэсэн үг юм. Гэхдээ энэ нь хүн бүрийн явах ёстой зам болохоор хэн ч айж түгших хэрэггүй. Сатаны уруу таталт хэд хэдэн хэлбэрээр ирж болно. Хэн нэгэн хүн Бурханы хэлдэг зүйлийг үл тоомсорлож, эсвэл орхиж магадгүй, мөн бусад хүмүүсийн эерэг байдлыг мохоохын тулд сөрөг зүйл хэлж ч магадгүй; гэхдээ ийм хүн ихэнхдээ бусад хүмүүсийг өөртөө татахгүй. Үүнийг ялган салгахад хэцүү байдаг. Үүний гол

шалтгаан нь энэ: Тийм хүн цуглаанд оролцохдоо идэвх санаачилгатай байж болох боловч үзэгдлүүдийн талаар тодорхой мэддэггүй. Хэрвээ чуулган түүнээс сэрэмжлэхгүй бол чуулган бүхэлдээ түүний сөрөг байдалд автан Бурханд хүйтэн хөндий хандаж, улмаар Бурханы үгэнд анхаарал хандуулахгүй байж болох юм— энэ нь Сатаны уруу таталтад автаж байгаа хэрэг юм. Тийм хүн Бурханы эсрэг шууд тэрслэхгүй байж болох ч Бурханы үгийг ойлгоогүй, Бурханыг мэдэхгүй учраас гомдоллож, эсвэл зүрх сэтгэлдээ гомдол дургүйцэл тээж магадгүй. Тэгээд Бурхан өөрийг нь орхисон болохоор гэгээрэл, гэрэлтүүлэлт хүлээн авах чадваргүй гэж хэлж болох юм. Тэрээр явахыг хүсэх ч бага зэрэг айх ба Бурханы ажил Бурханаас ирдэггүй, харин муу ёрын сүнсний ажил юм гэж хэлнэ.

Яагаад Бурхан Петрийг байн байн дурддаг вэ? Яагаад Тэр, Иов хүртэл түүнтэй эн зэрэгцэж чадаагүй гэж хэлдэг вэ? Ингэж хэлэх нь хүмүүсийг Петрийн үйл хэргийг анхаарахад хүргээд зогсохгүй, мөн зүрх сэтгэлдээ байгаа бүх үлгэр жишээг, хамгийн их итгэлтэй байсан Иовын үлгэр жишээг ч хойш тавихад хүргэдэг. Ийм маягаар л илүү дээр үр дүнд хүрч болох ба хүмүүс Петрийг дуурайхаар чармайн бүхнээ хойш тавьж, тэгснээрээ Бурханыг мэдэхэд нэг алхам ойртож чадна. Бурханыг мэдэхийн тулд Петрийн сонгосон хэрэгжүүлэлтийн замыг Бурхан хүмүүст харуулсан бөгөөд ингэхийн зорилго нь хүмүүст лавлагаа өгөхийн төлөө байдаг. Бурхан дараа нь “Гэхдээ хэрвээ чи Миний үгэнд хүйтэн хөндий, хайхрамжгүй ханддаг бол Намайг эргэлзээгүй эсэргүүцэж байна. Энэ бол бодит баримт” хэмээн хэлэх үедээ хүмүүсийг уруу татах Сатаны арга замуудын нэгийг зөгнөсөн юм. Эдгээр үгэнд Бурхан Сатаны ашиглахаар оролдох зальжин явуулгыг зөгнөсөн; тэдгээр нь сэрэмжлүүлэг болдог. Хүн бүр Бурханы үгэнд хайхрамжгүй ханддаг байх боломжгүй ч зарим хүн энэ уруу таталтад автана. Тиймээс эцэст нь Бурхан: “Хэрвээ та нар Миний үгийг мэддэггүй, хүлээн авдаггүй, хэрэгжүүлдэггүй бол Миний гэсгээлтийн бай болох нь гарцаагүй! Сатаны хохирогч болох нь гарцаагүй!” хэмээн дахин онцлон хэлсэн билээ. Энэ бол хүмүүст өгөх Бурханы зөвлөгөө, гэхдээ Бурханы зөгнөсөнчлөн эцэст нь хэсэг хүмүүс Сатаны хохирогчид болох нь лавтай.

9-Р БҮЛЭГ

Хүмүүсийн төсөөллөөр Бурхан бол Бурхан, хүмүүс бол хүмүүс. Бурхан хүмүүсийн хэлээр ярьдаггүй, мөн хүмүүс Бурханы хэлээр ярьж чадахгүй. Бурханы хувьд Өөрт нь тавьсан хүний шаардлагад хүрэхэд хялбархан байдаг байхад хүнд тавих Бурханы шаардлагууд нь хүмүүсийн хувьд хүрэхийн аргагүй, төсөөлөхийн аргагүй байдаг. Гэхдээ, үнэн яг эсрэгээрээ байдаг: Бурхан хүмүүсээс ердөө “0.1 хувийг” л шаарддаг. Энэ нь хүмүүст хачирхалтай байдгаар зогсохгүй, бас мэл гайхаж, будилахад тэднийг хүргэдэг. Бурханы гэгээрэл, нигүүлслийн ачаар л хүмүүс Бурханы хүслийн талаар бага зэрэг мэддэг болсон. Гэхдээ 3 дугаар сарын

1-нд бүх хүн дахин нэгэнтээ мэгдэж сандран, толгойгоо маажин үлдсэн юм; Бурхан Өөрийнхөө ардуудаас хөвөгч үүл биш, харин гялтганах цас байхыг шаардсан. Тэгвэл энэхүү “цас” юуг хэлдэг вэ? Мөн “хөвөгч үүл” нь юуг илтгэдэг вэ? Энэ мөчид, Бурхан эдгээр үгийн дотоод утга учрын талаар зориуд юу ч илчлээгүй. Энэ нь хүмүүсийг төөрөгдөлд умбуулж, улмаар эрж хайх итгэлийг нь нэмэгдүүлдэг—учир нь энэ бол Бурханы ардуудад тавьсан онцгой шаардлага бөгөөд өөр юу ч биш; тиймээс хүмүүс эдгээр ойлгохын аргагүй үгийг тунгаан бодоход өөрийн эрхгүй илүү их цаг зарцуулж байдаг. Үүний үр дүнд тэдний уураг тархинд янз бүрийн санаа төрж, хөвж буй цасан ширхэг нүднийх нь өмнүүр гялтганаж, тэнгэрт хөвөгч үүл нэн даруй оюун ухаанд нь харагддаг. Бурхан яагаад Өөрийнхөө ардуудаас хөвөгч үүл биш, харин цас байхыг шаарддаг вэ? Энд байгаа жинхэнэ утга учир юу вэ? Эдгээр үг яг юуг онцгойлон хэлдэг вэ? “Цас” нь байгалийг үзэсгэлэнтэй сайхан харагдуулаад зогсохгүй, бас хөдөө аж ахуйн бүс нутагт ч хэрэгтэй; энэ нь бактери устгахдаа сайн. Их цас орсны дараа бүх бактерийг гялтганах цас бүрхэж, бүхий л орон зай нэн даруй амьдралаар бялхдаг. Түүнчлэн, Бурханы ардууд бие махбодтой болсон Бурханыг мэдэх ёстойгоор үл барам, мөн Бурхан бие махбодтой болсон баримтын үндсэн дээр өөрсдийгөө захирдаг; ингэснээрээ тэд хэвийн хүн чанарыг амьдран харуулна. Цас ийнхүү байгалийг үзэсгэлэнтэй сайхан харагдуулдаг; эцсийн эцэст Бурханы ардуудын төлөвшил нь агуу улаан лууд төгсгөл авчирч, газар дээр Бурханы хаанчлалыг байгуулж, Бурханы ариун нэрийг түгээж, алдаршуулна, ингэснээр газар дээрх хаанчлал бүхэлдээ Бурханы зөвт байдлаар дүүрч, Бурханы гялбаагаар гэрэлтэж, Түүний алдраар очтон гялалзана. Хаа сайгүй амар тайван, сэтгэл хангалуун байдал, аз жаргал болон сэтгэл ханамж, тасралтгүй шинэчлэгдсэн гоо үзэсгэлэнгийн дүр зураг байх болно. Одоо оршин байгаа янз бүрийн тахал—зөв шударга бус байдал, гажууд, зальжин байдал, ёрын муу хүсэл гэх мэтийн завхарсан сатанлаг зан чанар—бүгд устгагдаж, улмаар тэнгэр, газар хоёулаа шинэчлэгдэнэ. Энэ бол “их цас орсны дараа” гэдгийн жинхэнэ утга учир юм. Хөвөгч үүл шиг хүмүүс нь Бурханы дурдсанаар бусдыг даган дуурайдаг төрлийн хүмүүс юм; хэрвээ Сатаны уруу таталт, эсвэл Бурханы шалгалт байвал тэд нэн даруй урсгал даган хөвж, оршин тогтнохоо болино. Тэдний аль хэдийн үгүй болсон мөн чанар ч гэсэн үлдэхгүй. Хэрвээ хүмүүс хөвөгч үүл шиг бол Бурханы дүрийг амьдран харуулах чадваргүйгээр үл барам, мөн Бурханы нэрд ичгүүр авчирдаг, учир нь тийм хүмүүс хэдийд ч, хаана ч булаагдан одох аюултай байдаг; тэд бол Сатаны иддэг хоол хүнс бөгөөд Сатан тэднийг олзлох үед Бурханаас урваж, Сатанд үйлчилнэ. Энэ нь Бурханы нэрд ичгүүр авчирдаг нь тодорхой бөгөөд Бурханы хамгийн их дургүйцдэг зүйл юм; ийм хүмүүс Бурханы дайснууд мөн. Тиймээс тэдэнд хэвийн хүмүүсийн мөн чанар, ямар нэг бодит үнэ цэнийн аль аль нь байдаггүй. Үүний улмаас Бурхан Өөрийн ардуудад тийм шаардлага тавьдаг. Гэвч эдгээр үгээс зарим нэг зүйлийг ойлгосныхоо дараа хүмүүс яахаа мэддэггүй, учир нь Бурханы үгийн сэдэв Бурхан руу Өөр лүү нь эргэсэн ба энэ нь тэднийг хэцүү

байр сууринд тавьдаг: “Би ариун газраас ирсэн учраас нэр төдий, мөн чанаргүй бадамлянхуа цэцэгтэй адил биш, учир нь тэр ариун газраас биш, харин намаг балчгаас гардаг билээ.” Өөрийн ардуудад тавих шаардлагынхаа талаар ярьсныхаа дараа Бурхан яагаад Өөрийнхөө төрөлтийг дүрсэлдэг вэ? Энэ хоёрын хооронд холбоо байдаг юм гэж үү? Үнэндээ тэдгээрийн хооронд төрөлхийн холбоо байдаг; эс бөгөөс Бурхан хүмүүст тэгж хэлэхгүй байх байсан юм. Ногоон навчсын дундах бадамлянхуа цэцэг зөөлөн салхины аясаар үргэлж нааш цааш ганхаж байдаг. Энэ нь нүдэнд тааламжтай агаад асар ихээр нандигнан хайрлагддаг. Хүмүүс зүгээр л үүнийг харж ханадаггүй бөгөөд ишнээс нь тасдан авч, ойроос харахын тулд усанд шумбахыг тэсэн ядан хүсэж байдаг. Гэсэн ч Бурхан, бадамлянхуа цэцэг намаг балчгаас гардаг ба мөн чанаргүй, зөвхөн нэр төдий гэж хэлдэг; Бурхан бадамлянхуа цэцгэнд ямар ч ач холбогдол өгдөггүй нь харагддаг бөгөөд үүнийг бага зэрэг үзэн яддаг гэдэг нь Түүний үгээс илэрхий байдаг. Бадамлянхуа цэцэг бохир заваан газраас өө сэвгүй гарч ирдэг болохоор эрин үеүдийн туршид олон хүн магтаал урсгаж, бүр үүнийг юутай ч харьцуулахын аргагүй, үгээр хэлэхийн аргагүй гайхалтай гэж хэлж байх шиг санагддаг. Гэхдээ Бурханы нүдээр бадамлянхуа цэцэг бол үнэ цэнгүй—энэ нь чухамдаа Бурхан, хүн хоёрын хоорондох ялгаа юм. Тиймээс Бурхан болон хүмүүсийн хоорондох ялгаа нь тэнгэр, газар шиг хол зөрүүтэй гэдгийг харж болно. Бадамлянхуа цэцэг намаг балчгаас ургадаг учраас үүнд шаардлагатай шим тэжээл ч бас бүгд тэндээс гардаг. Зүгээр л бадамлянхуа цэцэг зүсээ хувиргаж, улмаар нүд хужирладаг. Олон хүн бадамлянхуа цэцгийн үзэсгэлэнтэй сайхан гадаад талыг л хардаг боловч үүн дотор нуугдсан амь бузар, бохир гэдгийг хэн ч хардаггүй. Тиймээс Бурхан, үүнийг нэр төдий, мөн чанаргүй гэж хэлдэг—энэ нь бүхэлдээ үнэн, зөв юм. Бурханы ардууд өнөөдөр яг ийм байгаа биш гэж үү? Тэд зөвхөн гаднаа л Бурханд дуулгавартай байж, итгэдэг. Бурхан өөрсдөд нь сэтгэл ханамжтай байг гэсэндээ тэд Бурханы өмнө ая тал засаж, өөрсдийгөө харуулдаг; гэсэн ч дотроо тэд завхарсан сатанлаг зан чанараар дүүрэн, ходоод нь бохироор дүүрэн байдаг. Тийм учраас Бурхан хүмүүст асуулт тавьж, Бурханд хандах үнэнч зан нь хольцтой эсэхийг, мөн энэ нь ариун, чин үнэнч эсэхийг асуудаг. Үйлчлэл үзүүлэгчид байх үедээ олон хүн Бурханыг амаараа магтсан боловч зүрх сэтгэлдээ Түүнийг хараасан. Амаараа тэд Бурханд дуулгавартай байсан боловч зүрх сэтгэлдээ Түүнд дуулгаваргүй хандсан. Тэдний ам сөрөг үг хэлж, зүрх сэтгэлдээ тэд Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл өвөрлөсөн. Үйлдлүүд нь хоорондоо авцалдаатай хүмүүс ч байсан: Тэд амаараа бүдүүлэг хараал урсгаж, гараараа дохиж занган, туйлын садар самуун байж, агуу улаан лууны жинхэнэ төрхийг тод томруун, бодитоор илэрхийлсэн. Тийм хүмүүсийг агуу улаан лууны үр сад гэж нэрлэх нь үнэхээр зохистой. Гэхдээ өнөөдөр тэд үнэнч үйлчлэл үзүүлэгчдийн байранд зогсож, Бурханы үнэнч ардууд шиг авирладаг—хэчнээн ичгүүр сонжуургүй вэ! Гэвч гайхах юмгүй; тэд намаг балчгаас гарсан тул өөрийн эрхгүй жинхэнэ нүүр царайгаа харуулдаг. Бурхан ариун агаад цэвэр, бодит агаад жинхэнэ учраас Түүний махбод

Сүснээс ирдэг. Энэ нь лавтай агаад маргаангүй. Бурханд Өөрт нь гэрчлэл хийж чаддагаар үл барам, Бурханы хүслийг биелүүлэхэд Өөрийгөө бүрэн зориулж чаддаг: эдгээр нь Бурханы мөн чанарын нэг талыг төлөөлдөг. Дүр төрхтэй Сүснээс махбод ирдэг гэдэг нь, Сүнсний Өөрийгөө хувцасласан махбод бол хүний махан биеэс мөн чанартаа өөр гэсэн үг бөгөөд энэхүү ялгаа нь үндсэндээ тэдний сүнсэнд оршдог. “Дүр төрхтэй Сүнс” гэдэг нь, хэвийн хүн чанараар халхлагдсаны үр дүнд бурханлаг чанар нь дотроо хэвийн ажиллаж чаддаг гэдгийг хэлдэг. Энэ нь өчүүхэн ч ер бусын биш бөгөөд хүн чанараар хязгаарлагддаггүй. “Сүнсний дүр төрх” гэдэг нь бүрэн бурханлаг чанарыг хэлдэг ба хүн чанараар хязгаарлагддаггүй. Тийм болохоор Бурханы төрөлх зан чанар болон жинхэнэ дүр төрхийг, зөвхөн хэвийн, тууштай төдийгүй сүр жавхлан, уур хилэнтэй Бурханы махбод болсон бие л бүрэн амьдран харуулж чадна. Бурханы махбод болсон эхний бие нь хүмүүсийн үзлийн Бурханыг л харуулж байсан; өөрөөр хэлбэл, Тэрээр тэмдэг, гайхамшиг үзүүлж, зөгнөл хэлж л чаддаг байсан юм. Тиймээс Тэр Бурханы бодит байдлыг бүрэн амьдран харуулаагүй, иймд дүр төрхтэй Сүнсний биелэл байгаагүй юм; Тэр ердөө бурханлаг чанарын шууд илрэл байлаа. Түүнчлэн хэвийн хүн чанарыг даван гарсан учраас Түүнийг бүрэн бодитой Бурхан Өөрөө гэж нэрлээгүй, харин Түүнд тэнгэр дэх тодорхойгүй Бурханы зүйл бага зэрэг байсан; Тэр бол хүмүүсийн үзлийн Бурхан байсан юм. Энэ нь Бурханы махбод болсон хоёр биеийн мөн чанарын ялгаа билээ.

Бурхан орчлон ертөнцийн хамгийн өндөр цэгээс хүн төрөлхтний хөдөлгөөн бүрийг, хүмүүсийн хэлж, хийж байгаа бүхнийг хардаг. Тэрээр тэдний зүрх сэтгэлийн гүн дэх бодлыг ч орхигдуулахгүйгээр, туйлын тодорхой ажиглаж байдаг; иймээс Түүний үг хүмүүсийн зүрхийг зүсэж, бодол болгонд нь цохилт өгдөг бөгөөд Бурханы үг сүйхээтэй, алдаа мадаггүй байдаг. “Хүмүүс Миний Сүнсийг ‘мэддэг’ боловч Миний Сүнсэнд халдсаар байдаг. Миний үг бүх хүний муухай царайг ил гаргаж, бүх хүний зүрх сэтгэлийн хамгийн гүний бодлуудыг ч ил гаргадаг бөгөөд газар дээрх хүн бүхэн Миний шинжилтийн дунд нуран унадаг.” Хүнд тавих Бурханы шаардлага хэдийгээр өндөр биш боловч хүмүүс Бурханы Сүнсний шинжилтийг тэвчиж чаддаггүй гэдэг нь эндээс илэрхий байна. “Гэхдээ унаж, бүтэлгүйтсэн хэр нь тэдний зүрх сэтгэл Надаас холдон явж зүрхэлдэггүй. Бүтээгдсэн зүйлсийн дунд Миний үйл хэргээс болоод Намайг хайрладаггүй хэн байна?” Энэ нь Бурханы бүх мэргэн ухаан, бүхнийг чадагч байдлыг бүр ч их илтгэж, улмаар үйлчлэл үзүүлэгчдийн байр сууринд байх үедээ Бурханы ардуудын бодсон бүхнийг илчилдэг: Бүтэлгүйтсэн “арилжааг” дагаад тэдний уураг тархин дахь “хэдэн зуун мянга”, эсвэл “хэдэн сая” нь юу ч биш болсон. Гэхдээ Бурханы захиргааны зарлигаас болж, мөн Бурханы сүр жавхлан, уур хилэнгээс болж хэдий тэд уй гашуутайгаар толгойгоо унжуулсан ч сөрөг сэтгэхүйгээр Бурханд үйлчилсээр байсан бөгөөд урьдын бүх хэрэгжүүлэлт нь хоосон яриа болж, бүрмөсөн мартагдсан. Харин тэд өөрсдийгөө зугаацуулахын тулд, цаг өнгөрөөж, нөхцөөхийн төлөө өөрсдийг нь болон хүн бүрийг баярлуулах зүйлсийг хүссэнээрээ хийсэн… Хүмүүсийн дунд яг ийм зүйл болж байсан юм.

Тиймээс Бурхан хүнд хандан, ийнхүү хэлсэн: “Миний үгийн үр дүнд Намайг хүсэн эрмэлздэггүй хэн байна вэ? Миний хайраас болоод сэтгэл татагддаггүй хэн байна вэ?” Үнэнийг хэлэхэд хүмүүс бүгд Бурханы үгийг хүлээн авахад бэлэн байгаа ба Бурханы үгийг унших дургүй нэг ч хүн тэдний дунд үгүй; өөрсдийнх нь уг чанар саад болдог учраас тэд Бурханы үгийг хэрэгжүүлж ер чаддаггүй. Бурханы үгийг уншсаныхаа дараа олон хүн Бурханы үгээс салж тэвчдэггүй бөгөөд Бурханыг гэх хайр тэдний дотор ундардаг. Тиймээс Бурхан дахин нэгэнтээ Сатаныг харааж, үзэшгүй муухай царайг нь дахин нэгэнтээ илчилдэг. “Сатан цадиггүй аашлан галзуу мэт эзэрхэг байдаг эрин” гэдэг нь бас Бурхан газар дээрх албан ёсны, агуу ажлаа эхэлдэг яг тэр эрин үе юм. Дараа нь Тэр дэлхий ертөнцийг үндсээр нь устгах ажлаа эхэлдэг. Өөрөөр хэлбэл, Сатан хэдий чинээ их улангасан гүйнэ, Бурханы өдөр төдий чинээ хурдан ирнэ. Тиймээс Бурхан Сатаны дэггүй байдлын талаар ярих тусам, Бурхан дэлхий ертөнцийг үндсээр нь устгах өдөр улам ойртоно. Энэ нь Сатанд өгөх Бурханы тунхаглал юм.

Яагаад Бурхан: “…түүнчлэн Миний ар хударгаар тэд тэдгээр ‘магтууштай’ бохир ажлыг эрхэлдэг. Өөрийгөө хувцасласан бие махбод минь чиний үйлдэл, зан авир, үг хэлний талаар юу ч мэдэхгүй гэж чи бодож байна уу?” хэмээн ахин дахин хэлдэг юм бэ? Тэр ийм үгийг ганц, хоёрхон удаа хэлээгүй. Яагаад тэр вэ? Хүмүүс Бурханаар тайвшруулагдаж, хүнийг гэх Бурханы уй гашууг мэддэг болмогцоо урагш тэмцээд өнгөрснөө мартах нь амархан болдог. Гэхдээ Бурхан хүмүүст өчүүхэн төдий ч өршөөнгүй ханддаггүй: Тэрээр хүмүүсийн бодлыг мөшгөсөөр байдаг. Тиймээс Тэр хүмүүст өөрсдийгөө мэдэж, завхайрлаа зогсоож, тийм магтууштай бохир ажил хэрэгт оролцохоо больж, махбод дахь Бурханыг дахин хэзээ ч мэхлэхгүй бай гэж ахин дахин хэлдэг. Хэдийгээр хүмүүсийн уг чанар өөрчлөгддөггүй боловч тэдэнд хэдэн удаа сануулах нь ач тустай байдаг. Үүний дараа Бурхан доторх нууцуудыг нь илчлэхийн тулд хүний өнцгөөс ярьдаг: “Олон жил Би салхи, бороог тэсвэрлэж, хүний ертөнцийн гашууныг ч мөн амссан; гэхдээ сайн эргэцүүлэн бодвол ямар ч их зовлон шаналал махан биетэй хүнийг Надад итгэж найдахаа болиход хүргэхгүй, ямар ч сайхан байдал махан биетэй хүнийг Надад хүйтэн хөндий, сэтгэлээр унаж, үл ойшоосон байдлаар хандахад хүргэж бүр ч чадахгүй. Намайг гэх хүний хайр үнэхээр зовлон шаналалгүй юм уу сайхан байдалгүй байхаар хязгаарлагддаг юм уу?” “Нарны доорх бүхэн хий хоосон”—эдгээр үгэнд үнэндээ дотоод утга учир бий. Тиймээс Бурхан, юу ч хүнийг Түүнд итгэж найдахаа болиход хүргэж, эсвэл Түүнд хүйтэн хөндий хандахад хүргэж чадахгүй гэж хэлж байна. Хэрвээ хүмүүс Бурханыг хайрладаггүй бол тэд бараг үхсэн нь дээр; хэрвээ тэд Бурханыг хайрладаггүй бол тэдний зовлон хий дэмий, ерөөл нь хоосон бөгөөд нүгэл дээр нь нэмэгдэнэ. Бурханыг үнэхээр хайрладаг ганц ч хүн байдаггүй учраас Тэр: “Намайг гэх хүний хайр үнэхээр зовлон шаналалгүй юм уу сайхан байдалгүй байхаар хязгаарлагддаг юм уу?” гэж хэлсэн. Хүний ертөнцөд зовлон шаналал юм уу сайхан байдалгүйгээр хүн яаж оршин тогтнож чадах юм бэ? Бурхан: “Нэг ч хүн

Миний царайг үнэхээр хэзээ ч хараагүй, Миний дуу хоолойг ч хэзээ ч үнэхээр сонсоогүй, учир нь хүмүүс Намайг үнэхээр мэддэггүй” гэж ахин дахин хэлдэг. Хүмүүс Өөрийг нь үнэхээр мэддэггүй гэж Бурхан хэлдэг ч яагаад хүмүүсээс Өөрийг нь мэдэхийг шаарддаг юм бэ? Энэ нь зөрчилдөөн биш гэж үү? Бурханы үг бүр тодорхой зорилготой байдаг. Хүмүүс мэдрэмжгүй болсон учраас Бурхан эцэстээ хүн бүрийн зүрх сэтгэлийн 0.1 хувийг эзэмшихийн тулд хүмүүсээр дамжуулан Өөрийн ажлыг 100% хийх зарчмыг ашигладаг. Энэ нь Бурханы ажилладаг арга бөгөөд Бурхан Өөрийнхөө зорилгод хүрэхийн тулд ийнхүү ажиллах ёстой. Энэ нь бас чухамдаа Бурханы үгийн мэргэн ухаан билээ. Та нар үүнийг ухаарав уу?

Бурхан: “Би махбодоор Өөрийн нууцыг шууд илчилж, Өөрийн хүслийг ил болгох үед та нар анзаардаггүй; та нар дуу авиа сонсдог боловч утга учрыг нь ойлгодоггүй. Би уйтгар гунигт автдаг. Хэдийгээр Би махбодод байгаа боловч махбодын үйлчлэлийн ажлыг хийж чаддаггүй” гэж хэлдэг. Нэг талаар эдгээр үг, мэдрэмжгүй байдлаасаа болоод Бурхантай хамтран ажиллах санаачилга гаргахад хүмүүсийг хүргэдэг; нөгөө талаар Бурхан махбод дахь бурханлаг чанарынхаа жинхэнэ төрхийг илчилдэг. Хүмүүсийн биеийн хэмжээ хэтэрхий жаахан учраас Бурханыг махбодод байх үеийн бурханлаг чанарын илчлэл нь хүмүүсийн хүлээн авах чадварын л дагуу байдаг. Ажлын энэ үе шатанд ихэнх хүмүүс бүрэн хүлээн авах чадваргүй хэвээр үлддэг ба тэдний хүлээн авах чадвар хэчнээн ядмаг болохыг энэ нь хангалттай харуулдаг. Тиймээс энэ ажлын үеэр бурханлаг чанар анхдагч чиг үүргээ бүрэн биелүүлдэггүй; харин багахан хэсгийг нь л биелүүлдэг. Хожмын ажилд, хүний сэргэлтийн байр байдлын дагуу бурханлаг чанар аажмаар илчлэгдэнэ гэдгийг энэ нь харуулдаг. Гэсэн ч бурханлаг чанар аажмаар өсдөггүй; харин бие махбодтой болсон Бурханы мөн чанарт байдаг бөгөөд хүний биеийн хэмжээтэй адилгүй.

Бурхан хүмүүсийг бүтээсэн нь зорилготой, утга учиртай байсан, тиймээс Бурхан: “Хэрвээ хүмүүс бүгд Миний уур хилэнд устгагдах байсан бол тэнгэр газрыг бүтээсний минь утга учир юу байх вэ?” гэж хэлсэн юм. Хүмүүсийг завхруулагдсаны дараа Бурхан Өөрийнхөө таашаалын төлөө тэдний нэг хэсгийг олж авахаар төлөвлөсөн; Түүний санаа зорилго бүх хүнийг устгахын төлөө байгаагүй, мөн Бурханы захиргааны зарлигийг өчүүхэн төдий зөрчмөгц тэднийг үндсээр нь устгахын төлөө ч байгаагүй. Энэ нь Бурханы хүсэл биш юм; Бурханы хэлсэнчлэн, тэгэх нь утга учиргүй байх болно. Яг энэ “утгагүй байдлын” улмаас Бурханы мэргэн ухаан ил болдог. Бүх хүнийг гэсгээж, шүүж, цохихын тулд Бурхан олон арга замаар ярьж, ажиллаж, эцэстээ Өөрийг нь үнэхээр хайрладаг хүмүүсийг сонгодог нь бүр ч их ач холбогдолтой бус уу? Яг ийм байдлаар Бурханы үйл хэрэг илчлэгддэг тул хүмүүсийг бүтээсэн явдал бүр ч их утга учиртай болдог. Тиймээс Бурханы үгийн ихэнх нь тэдний хажуугаар өнгөрөн оддог гэж хэлдэг; энэ нь зорилгодоо хүрэхийн төлөө байдаг бөгөөд яг энэ нь л Түүний зарим үгийн бодит байдал билээ.

НЭМЭЛТ
1-Р БҮЛЭГ

Та нараас хийхийг хүсэж буй зүйл минь бол Миний ярьдаг тодорхойгүй, хоосон онол биш, мөн хүний ууриг тархиар төсөөлшгүй, хүний махан биеэр гүйцэтгэшгүй зүйл ч биш. Миний гэр дотроос хэн бүрэн дүүрэн үнэнч байх чадвартай вэ? Мөн Миний хаанчлал дотроос хэн өөртөө байгаа бүхнийг өргөн барьж чадах вэ? Миний хүсэл илчлэгдээгүй бол та нар Миний зүрх сэтгэлийг хангахыг өөрсдөөсөө үнэхээр шаардах байсан уу? Хэн ч, хэзээ ч Миний зүрх сэтгэлийг ойлгоогүй, хэн ч, хэзээ ч Миний хүслийг ухамсарлаагүй. Хэн ер нь Миний царайг харж, Миний дуу хоолойг сонссон бэ? Петр үү? Паул уу? Иохан уу? Эсвэл Иаков уу? Хэн ер нь Надаар хувцаслуулж, Надад эзэмдүүлж, эсвэл Надад ашиглагдсан юм бэ? Хэдийгээр анх удаа махбод болсон минь бурханлаг чанар дотор тохиолдож, Өөрийгөө хувцасласан махбод минь хүний зовлонг мэдээгүй ч Би дүр төрхтэйгөөр бие махбодтой болоогүй учраас Миний хүслийг махбод бүрэн биелүүлсэн гэж хэлж болохгүй. Миний бурханлаг чанар ямар ч саад бартаагүйгээр, хэвийн хүн чанартай хүний хувиар Миний хийх зүйлийг хийж, хэлэх зүйлийг хэлж байгаа цагт л Миний хүсэл махбодоор гүйцэтгэгддэг гэж хэлж болно. Миний хэвийн хүн чанар бурханлаг чанарыг минь халхалж чаддаг учраас даруухан, нууцлаг байх гэсэн Миний зорилгыг биелүүлдэг. Махбодоор ажиллах үе шатанд хэдийгээр бурханлаг чанар шууд үйлддэг боловч хүмүүсийн хувьд тийм үйлдлүүдийг харахад амаргүй байдаг ба энэ нь ердөө хэвийн хүн чанарын амьдрал болон үйлдлээс болдог. Бие махбодтой болсон энэ Бурхан эхний удаа бие махбодтой болсон шигээ 40 өдрийн турш мацаг барьж чадахгүй ч хэвийн байдлаар ажиллаж, үгээ хэлдэг; хэдийгээр нууцуудыг илчилдэг ч Тэр тун хэвийн байдаг; хүмүүсийн төсөөлдөг шигээр Түүний дуу хоолой аянга шиг биш, мөн Түүний нүүр царай гэрэлтэн гялалздаггүй, Түүнийг алхах үед тэнгэрүүд доргидоггүй. Хэрвээ тийм байсан бол тэнд Миний мэргэн ухаан огт байхгүй байх байсан ба Сатаныг ичээж, ялж чадахгүй байх байсан юм.

Хэвийн хүн чанарын халхавчны ардаас бурханлаг чанараа харуулах үедээ Би бүрэн алдар сууг олж авч, Миний агуу ажил гүйцэлддэг бөгөөд юу ч, ямар ч бэрхшээл учруулдаггүй. Учир нь бие махбодтой болсон Миний зорилго бол үндсэндээ Надад итгэдэг бүх хүнд махбод дахь бурханлаг чанарынхаа үйл хэргийг харуулж, бодитой Бурханыг Өөрийг нь харуулж, улмаар хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдсэн нүдэнд үл үзэгдэж, гарт үл баригдах Бурханы орон зайг арилгах явдал юм. Би хооллож, хувцаслаж, унтаж, амьдарч, хэвийн хүн шиг үйлддэг учраас, мөн хэвийн хүн шиг ярьж, инээж, хэвийн хүний хэрэгцээтэй байхын сацуу бүрэн бурханлаг чанарын мөн чанарыг эзэмшдэг учраас Намайг “бодитой Бурхан” гэж нэрлэдэг. Энэ нь хийсвэр биш бөгөөд үүнийг ойлгоход амархан; Миний ажлын гол цөм аль хэсэгт оршиж байгааг, мөн Миний анхаарал ажлын аль үе шатанд байгааг үүнээс харж болно. Хэвийн хүн чанараар дамжуулан бурханлаг чанараа илчлэх нь

бие махбодтой болсон Миний гол зорилго юм. Миний ажлын төв нь шүүлтийн эриний хоёр дахь хэсэгт байдаг гэдгийг харахад хэцүү биш.

Надад хүний амь ч, хүний ямар нэгэн ул мөр ч хэзээ ч байгаагүй. Хүний амь Миний дотор хэзээ ч зай эзэлж байгаагүй бөгөөд Миний бурханлаг чанарын илчлэлээс хэзээ ч давж байгаагүй. Тиймээс, тэнгэр дэх Миний дуу хоолой болон Миний Сүнсний хүсэл илэрхийлэгдэх тусам, Сатаныг төдий чинээ их шившиглэж чадах тул Миний хүслийг хэвийн хүн чанараар гүйцэтгэхэд төдий чинээ амархан болдог. Энэ нь дангаараа Сатаныг ялсан; Сатан аль хэдийн бүрэн шившиглэгдсэн. Хэдийгээр Би нуугдмал байдаг боловч энэ нь Миний бурханлаг чанарын айлдварууд болон үйлдлүүдэд саад болдоггүй—Би ялалт байгуулсан, бүрэн алдар сууг олж авсан гэдгийг энэ нь хангалттай харуулдаг. Махбод дахь Миний ажил саадгүй байдаг учраас, мөн бодитой Бурхан одоо хүмүүсийн зүрх сэтгэлд зай эзэлж, тэдний зүрх сэтгэлд үндсээ суулгасан учраас Сатан Надад ялагдсан гэдэг нь бүрэн батлагддаг. Сатан хүмүүсийн дунд өөр юу ч хийх чадваргүй учраас, хүний махан биед Сатаны хэв чанарыг нэмэхэд хэцүү учраас Миний хүсэл саадгүйгээр урагшилна. Миний ажлын агуулга нь ерөнхийдөө бүх хүнд Өөрийн гайхалтай үйл хэргийг харуулж, Өөрийн жинхэнэ нүүр царайг харуулах явдал: Би бол хүрэхийн аргагүй биш, Би тэнгэрт сүндэрлэдэггүй, мөн Би хэлбэр дүрсгүй, эх захгүй биш. Би агаар шиг үзэгддэггүй биш, мөн салхинд амархан туугддаг хөвөгч үүл шиг ч биш; харин хэдийгээр Би хүмүүсийн дунд амьдарч, хүмүүсийн дунд чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай байдлыг туулдаг ч Миний махбод мөн чанарын хувьд хүнийхээс өөр юм. Ихэнх хүмүүсийн хувьд Надтай харилцахад хэцүү байдаг, гэсэн ч ихэнх нь бас Надтай харилцахаар хүсэн эрмэлздэг. Бие махбодтой болсон Бурханы дотор үлэмж их, ойлгохын аргагүй нууц байгаа мэт л байдаг. Бурханлаг чанарын шууд илчлэлээс үүдэн, мөн хүний гадаад төрхийн халхавчаас үүдэн хүмүүс Надаас хүндэтгэлтэйгээр зай барьж, Намайг өршөөнгүй, элэгсэг Бурхан гэдэгт итгэдэг атлаа Миний сүр жавхлан, уур хилэнгээс бас айж байдаг. Тиймээс зүрх сэтгэлдээ тэд Надтай үнэн сэтгэлээсээ ярихыг хүсдэг ч хүссэнээрээ хийж чаддаггүй—зүрх сэтгэлдээ хүсэж байгаа зүйлд нь тэдний хүч чадал дутагддаг. Энэ нь ийм нөхцөлд байгаа хүн бүрийн нөхцөл байдал бөгөөд хүмүүс ийм байх тусам, Миний зан чанарын янз бүрийн талуудын илчлэлийн нотолгоо улам их байна, тийнхүү Бурханыг мэдэх гэсэн хүмүүсийн зорилго биелдэг. Гэхдээ энэ бол хоёрдогч зүйл; гол зүйл нь Өөрийнхөө махбодын хийж байгаа зүйлээр дамжуулан гайхалтай үйл хэргээ хүмүүст мэдэгдэж, Бурханы мөн чанарыг мэдүүлэх явдал юм; Би бол хүмүүсийн төсөөлдөг шиг хэвийн бус, ер бусын биш. Харин ч Би бол бүх зүйл дээр хэвийн байдаг бодитой Бурхан билээ. Хүмүүсийн үзэл дэх Миний орон зай арилж, тэд Намайг бодит байдал дээр мэдэж авдаг. Тэгсэн цагт л Би хүмүүсийн оюун ухаанд Өөрийн жинхэнэ орон зайг эзэлж чадна.

Бүх хүний өмнө Би хүмүүсийн нандигнасаар ирсэн ямар нэгэн ер бусын зүйлийг хэзээ ч хийж байгаагүйгээр үл барам, туйлын эгэл жирийн, хэвийн байдаг; Би

Өөрийнхөө махбод болсон бие дэх Бурханы ямар нэг сэжүүрийг агуулсан зүйлийг зориуд хүмүүст харуулдаггүй. Гэхдээ Миний үгээс үүдэн хүмүүс бүрмөсөн байлдан дагуулагдаж, Миний гэрчлэлд захирагддаг. Тэгж байж л хүмүүс Бурхан үнэхээр оршин байдаг гэж бүрэн итгэсэн суурин дээрээс махбод дахь Намайг болгоомжлолгүйгээр мэдэж авдаг. Ийм маягаар Миний талаарх хүмүүсийн мэдлэг илүү бодитой, илүү тодорхой болдог ба тэдний сайн ааш авир өчүүхэн төдий ч холилдоогүй байдаг; энэ бүхэн нь Миний бурханлаг чанар шууд үйлдэж байгаагийн үр дүн бөгөөд хүмүүст Миний бурханлаг чанарын талаар асар их мэдлэг өгдөг, учир нь зөвхөн бурханлаг чанар л Бурханы жинхэнэ нүүр царай, мөн Бурханы төрөлхийн онцлог шинж билээ. Хүмүүс үүнийг харах ёстой. Би бурханлаг чанарын үг, үйл хэрэг болон үйлдлийг л хүсдэг—харин хүн чанарын үг, үйлдлийг анхаардаггүй. Миний зорилго бол бурханлаг чанараар амьдарч, үйлдэх явдал—Би хүн чанарт үндэслэж, нахиалахыг хүсдэггүй, хүн чанараар амьдрахыг хүсдэггүй. Та нар Миний хэлж байгаа зүйлийг ойлгож байна уу? Хэдийгээр Би хүн төрөлхтний дундах зочин боловч Би үүнийг хүсдэггүй; Би бүрэн бурханлаг чанараар үйлддэг ба ийм маягаар л хүмүүс Миний жинхэнэ нүүр царайг илүү сайн ойлгож чадна.

10-Р БҮЛЭГ

Чуулганыг байгуулах цаг үед Бурхан хаанчлалыг байгуулах талаар бараг дурдаагүй. Дурдах үедээ ч гэсэн тухайн үеийн хэлээр хэлсэн. Хаанчлалын эрин үе ирмэгц Бурхан чуулган байгуулах цаг үеийн тодорхой арга барил, үйл хэргийг ганцхан зураас татан хүчингүй болгосон бөгөөд эдгээрийн талаар дахин хэзээ ч ганц ч үг айлдаагүй билээ. Энэ нь яах аргагүй, үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй “Бурханы Өөрийн” үндсэн утга учир юм. Түүнчлэн өнгөрсөн үед аливаа зүйл хийгдсэн байж болох ч эцсийн эцэст тэдгээр нь улирсан баларсан эрин үеийн нэг хэсэг учраас Бурхан урьдын тийм үйл явдлуудыг Христийн өмнөх цаг хугацаанд тохиолдсон хэмээн ангилдаг, харин өнөө үеийг Христийн дараах цаг үе гэдэг. Чуулганыг байгуулах явдал нь хаанчлалыг байгуулах урьдач нөхцөл юм гэдгийг үүнээс харж болно; энэ нь Бурханы хаанчлалд дээд эрх мэдлээ эзэмших суурийг тавьсан. Чуулганы бүтээн байгуулалт нь өнөөдрийн товч дүрслэл юм; газар дээрх Бурханы ажил нь хаанчлалыг байгуулах энэхүү хэсэгт анхаарлаа голчлон төвлөрүүлдэг. Чуулганыг байгуулж дуусахаасаа өмнө Бурхан хийгдэх бүх ажилд зориулсан бэлтгэлийг аль хэдийн хийсэн бөгөөд цаг нь болоход албан ёсоор ажлаа эхэлжээ. Тиймээс Бурхан: “Хаанчлалын эрин үе эцсийн эцэст өнгөрсөн үеэс ялгаатай. Энд хүн яаж авирладаг нь хамаагүй; харин ч Би ажлаа биечлэн гүйцэтгэхээр газар дээр бууж ирсэн бөгөөд энэ нь хүмүүсийн ухамсарлаж ч чадахгүй, биелүүлж ч чадахгүй зүйл юм” гэж хэлсэн билээ. Үнэндээ энэ ажлыг Бурхан биечлэн гүйцэтгэх ёстой—нэг ч хүн ийм ажил хийж чадахгүй; тэд чухамдаа үүнийг хүчрэхгүй.

Хүмүүсийн дундах ийм агуу ажлыг Бурханаас өөр хэн гүйцэтгэж чадах юм бэ? Өөр хэн, бүх хүнийг хагас үхлүүт болтол нь “тарчилгаж” чадах вэ? Хүмүүс ийм ажил зохицуулж ер нь чадах уу? Яагаад Тэр: “Би ажлаа биечлэн гүйцэтгэхээр газар дээр бууж ирсэн” гэж хэлсэн юм бэ? Бурханы Сүнс бүх сансар огторгуйгаас үнэхээр алга болчихсон юм гэж үү? “Би ажлаа биечлэн гүйцэтгэхээр газар дээр бууж ирсэн” гэх мөр нь Бурханы Сүнс ажлаа хийхээр бие махбодтой болсон баримт болон Бурханы Сүнс хүмүүсээр дамжуулан ажиллаж байгаа нь гарцаагүй гэх баримтыг хоёуланг нь илэрхийлдэг. Өөрийн ажлыг биечлэн гүйцэтгэснээрээ Тэрээр олон хүнд Бурханыг Өөрийг нь энгийн нүдээр харах боломж олгодог; тэд Түүнийг сүнсэн дотроо хянамгай хайх шаардлагагүй. Түүнчлэн, Тэрээр Сүнсний үйл ажиллагааг нүдээрээ харах боломжийг бүх хүнд олгож, хүний махан бие болон Бурханы махбодын хооронд мөн чанарын ялгаа байдгийг харуулдаг. Үүний зэрэгцээ бүх сансар огторгуй, дэлхий ертөнц даяар Бурханы Сүнс ажиллаж байгаа. Бурханы гэгээрсэн бүх ард түмэн Бурханы нэрийг хүлээн зөвшөөрснийхөө дараа Бурханы Сүнс хэрхэн ажилладгийг харж, улмаар бие махбодтой болсон Бурханыг бүр сайн мэдэж авдаг. Тийм болохоор Бурханы бурханлаг чанар шууд ажиллах л юм бол, өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс өчүүхэн төдий ч хөндлөнгийн оролцоогүйгээр ажиллаж чадах үед л хүмүүс бодитой Бурханыг Өөрийг нь мэдэж авч чадна. Энэ нь хаанчлалыг байгуулахын мөн чанар юм.

Бурхан хэдэн удаа бие махбодтой болсон бэ? Хэд хэдэн удаа байж таарах уу? Яагаад Бурхан: “Би нэгэн удаа хүний ертөнцөд буун ирж, тэдний зовлон шаналлыг туулж, ажигласан хэдий ч бие махбодтой болсон Өөрийн зорилгыг гүйцэлдүүлээгүй” гэж олон удаа хэлсэн юм бэ? Бурхан хэд хэдэн удаа бие махбодтой болсон боловч хүмүүс ганц ч удаа мэдээгүй гэж үү? Энэ үг тийм утгатай биш. Эхний удаа бие махбодтой болоход Бурханы зорилго нь үнэндээ хүмүүст Өөрийгөө мэдэгдэхийн төлөө байгаагүй; харин ч Тэрээр ажлаа гүйцэтгээд, дараа нь хэнд ч анзаарагдалгүйгээр, Өөрийг нь мэдэх боломж ч олголгүйгээр алга болсон. Түүнийг бүрэн мэдэх боломжийг Тэр хүмүүст олгоогүй, мөн бие махбодтой болохын ач холбогдлыг ч бүрэн эзэмшээгүй; иймээс Түүнийг бүрэн дүүрэн бие махбодтой болсон гэж хэлж болохгүй. Эхний удаа бие махбодтой болохдоо Бурхан ердөө тэрхүү ажлыг гүйцэтгэхийн тулд л нүгэлт чанаргүй махбодыг ашигласан; ажил дууссаны дараа цаашид дурдах хэрэг байгаагүй. Эрин үеүдийн туршид Бурханы ашиглаж байсан хүмүүсийн тухайд бол тийм тохиолдлуудыг “бие махбодтой болох” гэж нэрлэх нь бүр ч зохисгүй. Хэвийн хүн чанарын бүрхүүлтэй, дотроо бүрэн бурханлаг чанартай, Өөрийг нь мэдэх боломжийг хүмүүст олгох зорилготой, өнөөдрийн бодитой Бурханыг Өөрийг нь л “бие махбодтой болсон” гэж хэлж болно. Энэ дэлхийд хийсэн Бурханы эхний айлчлалын ач холбогдол нь өнөөдөр бие махбодтой болох гэж нэрлэгддэг зүйлийн ач холбогдлын нэг тал юм—гэхдээ энэ айлчлал нь бие махбодтой болох гэгддэг зүйлийн бүрэн гүйцэд ач холбогдлыг яавч агуулдаггүй. Ийм учраас Бурхан: “бие махбодтой болсон Өөрийн ач холбогдлыг гүйцэлдүүлээгүй” гэж хэлсэн. Бурханы үгэнд хэлснээр хүмүүсийн зовлон шаналлыг

туулж, ажиглах гэдэг нь Бурханы Сүнс болон хоёр удаа бие махбодтой болсон Бурханыг хэлдэг. Иймээс Бурхан: “Хаанчлалыг байгуулж эхлэх үед Миний махбод болсон бие албан ёсоор үйлчлэлээ гүйцэтгэж эхэлдэг; өөрөөр хэлбэл, хаанчлалын Хаан Өөрийн дээд эрх мэдлийг албан ёсоор авдаг” гэсэн. Хэдийгээр чуулганыг барьж байгуулах нь Бурханы нэрийг гэрчлэх гэрчлэл байсан боловч ажил хараахан албан ёсоор эхлээгүй байв; өнөөдөр л үүнийг хаанчлалыг байгуулах явдал гэж нэрлэж болно. Урьд нь хийгдсэн бүхэн ердөө урьдчилсан загвар байлаа; энэ нь бодитой зүйл байгаагүй. Хэдийгээр хаанчлал эхэлсэн гэж хэлсэн боловч үүн дотор ямар ч ажил хараахан хийгдээгүй байсан. Зөвхөн өнөөдөр л, Бурханы бурханлаг чанар дотор ажил хийгдэж, Бурхан Өөрийн ажлыг албан ёсоор эхэлсэн болохоор хүмүүс эцэст нь хаанчлалд орсон. Тиймээс, “хаанчлал хүний ертөнцөд бууж ирсэн нь үгчилсэн илрэл төдийхөн биш, харин бодит байдал гэдэг нь илт юм; энэ бол ‘хэрэгжүүлэлтийн бодит байдлын’ утга учрын нэг тал юм.” Энэ эшлэл нь дээрх тайлбарын оновчтой дүгнэлт билээ. Ийм тодорхойлолт өгснийхөө дараа Бурхан цааш нь хүн төрөлхтний ерөнхий байдлыг дүрсэлж, хүмүүсийг байнгын завгүй байр байдалтай орхисон. “Дэлхий даяар хүн бүр Миний өршөөл, Миний хайр энэрэл дотор оршдог, гэвч бас бүх хүн Миний шүүлтэн дор, түүнчлэн Миний шалгалтан дор оршдог.” Хүний амьдрал нь Бурханы тогтоосноор тодорхой зарчим, хууль дүрэмд захирагддаг ба энэ нь дараах байдалтай байдаг: Аз жаргалтай үе, сэтгэлээр унах мөч, түүнчлэн тэвчих ёстой зовлон бэрхшээлээр цэвэршүүлэгдэх цаг үе байх болно. Тиймээс ямар ч хүн цэвэр аз жаргал, эсвэл цэвэр зовлонгийн амьдралаар амьдрахгүй. Бүхий л амьдралд сайн муу ээлжлэн байх болно. Бүх хүн төрөлхтөн даяар Бурханы хайр, энэрэл илэрхий байгаад зогсохгүй, мөн Түүний шүүлт болон бүхий л зан чанар илэрхий байдаг. Бүх хүн Бурханы шалгалтан дунд оршин байдаг гэж хэлж болно, тийм биз дээ? Энэхүү өргөн уудам дэлхий ертөнц даяар хүмүүс өөрсдийн гарах гарцыг олох гээд завгүй байдаг. Тэд ямар үүрэг гүйцэтгэдгээ мэддэггүй, зарим нь бүр хувь заяаныхаа төлөө амьдралаа сүйтгэж, эсвэл алддаг. Иов хүртэл энэ дүрмээс ангид байгаагүй: Хэдий тэр ч бас Бурханы шалгалтыг туулсан ч гэсэн өөртөө гарах гарц хайсан. Хэн ч, хэзээ ч Бурханы шалгалтад бат зогсож чадаагүй. Хүний шунал, уг чанараас үүдэн хэн ч одоогийн нөхцөл байдалдаа бүрэн сэтгэл ханадаггүй бөгөөд хэн ч шалгалтад бат зогсдоггүй; хүн бүр Бурханы шүүлтэн дор нуран унадаг. Хэрвээ Бурхан хүмүүст нухацтой хандсан бол, хэрвээ хүмүүст тийм хатуу чанд шаардлага тавьсаар байсан бол яг л Түүний хэлсэнчлэн: “Бүх хүн Миний дүрэлзсэн харцан дор нуран унах байсан.”

Хаанчлалын бүтээн байгуулалт албан ёсоор эхэлсэн хэдий боловч хаанчлалын ёслолын буудлага хараахан албан ёсоор дуугараагүй; одоо энэ нь болох гэж буй зүйлийн талаарх зөгнөл төдий байгаа. Хүмүүс бүгд бүрэн төгс болгуулж, газар дэлхийн бүх үндэстэн Христийн хаанчлал болох үе нь долоон аянга нижигнэх үе байх болно. Одоо үе бол тэрхүү үе шат руу урагшлах алхаа; тэрхүү өдөрт хандсан довтолгоо хийгдсэн. Энэ бол Бурханы төлөвлөгөө бөгөөд ойрын ирээдүйд энэ нь

биелнэ. Гэхдээ Бурхан хэлсэн бүхнээ аль хэдийн гүйцэлдүүлчихсэн. Тиймээс газар дэлхийн улс үндэстнүүд нь, далайн түрлэг ойртохын хэрээр чичрэн доргиж байгаа элсэн дээрх цайз төдий юм гэдэг нь тодорхой: Эцсийн өдөр айсуй бөгөөд агуу улаан луу Бурханы үгэн дор нуран унана. Бурханы төлөвлөгөөг гарцаагүй амжилттай гүйцэтгэхийн тулд тэнгэрийн тэнгэрэлчүүд газар дээр буун ирж, Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд чадах бүхнээ хийсэн. Бие махбодтой болсон Бурхан Өөрөө дайсантай тулалдахын тулд тулааны талбарт байрласан. Бие махбодтой болсон Бурхан хаана илрэн гарна, тэр газарт байгаа дайсан устгагддаг. Хятад улс хамгийн эхлээд бүрмөсөн устгагдана; тэгээд Бурханы гарт сүйрнэ. Бурхан яавч өршөөл үзүүлэхгүй. Агуу улаан лууны эрчимтэй сүйрлийн нотолгоог ардуудын тасралтгүй төлөвшлөөс харж болно; энэ нь хэн бүхэнд илэрхий, ил байдаг. Ардуудын төлөвшил нь дайсан сөнөсний тэмдэг юм. “Тулалдах” гэдгийн багахан тайлбар энэбилээ. Тиймээс үзэл буюу агуу улаан лууны үзэшгүй муухай байдлын, хүмүүсийн зүрх сэтгэлд эзэлж буй байр суурийг төгсгөхийн тулд Өөрт нь сайхан гэрчлэл хий гэж Бурхан хүмүүст тоо томшгүй олон удаа сануулсан. Бурхан, хүний итгэлийг сэргээж, улмаар ажилдаа үр дүнд хүрэхийн тулд ийм сануулга ашигладаг. Ийм учраас Бурхан: “Хүн юу хийх чадвартай вэ? Харин ч Би үүнийг Өөрөө хийдэг биш гэж үү?” хэмээн хэлсэн. Бүх хүн ийм байдаг; тэд чадваргүй байдгаар үл барам бас амархан шантарч, сэтгэлээр унадаг. Энэ шалтгааны улмаас тэд Бурханыг мэдэж чаддаггүй. Бурхан хүмүүсийн итгэлийг сэргээгээд зогсохгүй, бас хүмүүст нууцханаар, байнга хүч чадал шингээж байдаг.

Дараа нь Бурхан бүхий л орчлон ертөнцөд хандан үг хэлж эхэлсэн. Бурхан Өөрийн шинэ ажлыг хятадад эхлүүлээд зогсохгүй, бүхий л орчлон ертөнц даяар өнөөдрийн шинэ ажлыг хийж эхэлсэн. Ажлын энэ үе шатанд Бурхан Өөрийн бүх үйл хэргийг дэлхий даяар илчлэхийг хүсдэг учраас Өөрөөс нь урвасан бүх хүн сэнтийнх нь өмнө захирагдахаар дахин ирэг гэсэндээ Бурханы шүүлт өршөөл, хайр энэрэл агуулсаар байх болно. Бурхан хүмүүсийг самгардуулахын тулд дэлхий даяарх одоогийн үйл явдлуудыг ашиглан, Бурханыг эрж хайх сэдэл төрүүлдэг, ингэснээр тэд Түүн рүү буцан урсаж болох юм. Тиймээс Бурхан “Энэ нь Миний ажилладаг арга замуудын нэг, мөн хүнийг аврахын төлөө гэдэг нь эргэлзээгүй бөгөөд тэдэнд Миний хүртээдэг зүйл бол мөн л нэг төрлийн хайр юм” гэдэг. Бурхан гярхай, зүйрлэшгүй, хялбархан нарийвчлалтайгаар хүмүүсийн жинхэнэ уг чанарыг ил болгодог. Энэ нь хүмүүсийг нүүр хийх газаргүй болгож, туйлын шившигтэй байдалд оруулж орхидог. Бурхан үг хэлэх болгондоо хүний ичгүүртэй гүйцэтгэлийн зарим талыг заан үзүүлж амждаг, ингэснээр хүмүүс санаа амар байх зуураа өөрсдийгөө мэдэж авахаа мартдаггүй бөгөөд өөрсдийгөө мэдэх нь хуучин даалгавар гэж боддоггүй. Хүний уг чанарын дагуу, хэрвээ Бурхан тэдний алдааг ганцхан хормын төдийд зааж үзүүлэхээ болих юм бол тэд садар самуун, биеэ тоосон зантай болох магадлалтай. Ийм учраас өнөөдөр Бурхан: “Хүмүүс Миний олгосон цолыг огтхон ч эрхэмлэн дээдэлдэггүй, харин ‘үйлчлэл үзүүлэгч’ гэдэг

цолоос үүдэн зүрх сэтгэлдээ гомдол агуулж явдаг нь их олон бөгөөд ‘Миний ард’ гэдэг цолоос үүдэн зүрх сэтгэлдээ Намайг гэх хайраа өсгөдөг хүн олон байдаг. Хэн ч Намайг мэхлэхээр оролдох ёсгүй; Миний нүд бүхнийг хардаг!” гэж дахин хэлдэг. Хүмүүс энэ үгийг хармагцаа нэн даруй тавгүйтдэг. Урьдын үйлдлүүд нь хэтэрхий төлөвшөөгүй—Бурханд халддаг нэг төрлийн бохир наймаа л байсныг тэд мэдэрдэг. Тэр саяхнаас л Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг хүссэн боловч тэгж их хүсдэг хэр нь тийнхүү хийх хүч чадал дутмаг байдаг бөгөөд яах учиртайгаа мэддэггүй. Тэд өөрийн мэдэлгүй шинэхэн шийдвэртэй болсон байдаг. Энэ нь хүн тайвширсныхаа дараа эдгээр үгийг уншсаны үр нөлөө юм.

Нэг талаар Бурхан, Сатаныг туйлын галзуу гэж хэлдэг мөртөө нөгөө талаар бас, ихэнх хүнд байдаг хуучин уг чанар өөрчлөгдөөгүй гэж хэлдэг. Үүнээс харахад, Сатаны үйлдлүүд хүмүүсээр дамжин илэрхийлэгддэг нь илэрхий байна. Тиймээс Бурхан, Сатанд залгиулахгүйн тулд садар самуун бүү бай гэж хүмүүст удаа дараа сануулдаг. Энэ нь, зарим хүн тэрслэх болно гэдгийг зөгнөөд зогсохгүй, түүнчлэн өнгөрснөө яаран хойш тавьж, өнөөдрийг эрж хай хэмээн бүх хүнд анхааруулан хангинаж буй түгшүүрийн дохио юм. Хэн ч чөтгөрүүд юм уу муу ёрын сүнснүүдэд эзэмдүүлэхийг хүсдэггүй тул Бурханы үг тэдэнд бүр ч их анхааруулга, сэрэмжлүүлэг болдог. Гэсэн ч ихэнх хүн дэндүү их туйлширч, Бурханы сүүлчийн үг нэг бүрд асар их ач холбогдол өгөх үед Бурхан хариуд нь: “Ихэнх хүн нүдээ хужирлахын тулд улам олон нууц илчлэхийг минь хүлээдэг. Гэсэн ч тэнгэрийн бүх нууцыг ойлголоо гэхэд чи тэр мэдлэгээрээ юу хийж чадах юм бэ? Энэ нь Намайг гэх хайрыг чинь ихэсгэх байсан уу? Энэ нь Намайг гэх хайрыг чинь төрүүлэх байсан уу?” гэдэг. Эндээс харахад, хүмүүс Бурханыг мэдэхийн тулд, Бурханыг хайрлахын тулд биш, харин өөрсдийн “жижигхэн агуулахын” нөөцийг ихэсгэхийн тулд л Бурханы үгийг ашигладаг гэдэг нь илэрхий байна. Тиймээс Бурхан хүмүүсийн хэт туйлшралыг дүрслэхийн тулд “нүдээ хужирлах” хэмээх хэллэгийг ашигласан нь Бурханыг гэх хүмүүсийн хайр одоо ч цэв цэвэрхэн биш байгааг илтгэдэг. Хэрвээ Бурхан нууцуудыг илчлээгүй бол хүмүүс Түүний үгэнд тийм ч их ач холбогдол өгөхгүй байх байсан, харин ч тэдгээрийг зүгээр л зэрвэсхэн харж, морин дэл дээр давхин өнгөрөхдөө цэцэгсийг бахдан гайхах мэт хальтхан харах байлаа. Тэд Түүний үгийг үнэхээр эргэцүүлж, тунгаан бодох цаг гаргахгүй байх байв. Ихэнх хүн Бурханы үгийг үнэхээр нандигнадаггүй. Түүний үгийг идэж уухын тулд шаргуу ажилладаггүй, харин зүгээр л хааш яаш гүйлгэн хардаг. Яагаад Бурхан одоо өнгөрсөн үеийнхээсээ өөр байдлаар ярьдаг юм бэ? Яагаад Түүний бүх үг тийм ойлгошгүй байдаг юм бэ? Жишээлбэл, “Би хүмүүст ийм хаяг шошгыг хэзээ ч санамсаргүйгээр титэм адилаар өмсгөхгүй” гэдэгт байгаа “титэм”, мөн “Миний үгийн шижир алтан бүтээгдэхүүнийг өөртөө хүлээн авч чадах хэн нэгэн байна уу?” гэсэн дэх “шижир алт”, урьд нь Түүний дурдаж байсан “Сатаны ямар ч боловсруулалтаар дамжилгүй” гэдэгт буй “боловсруулалт” гэх мэт. Бурхан яагаад ийм маягаар ярьдгийг хүмүүс ойлгодоггүй; Тэр яагаад ийм алиа, хошин, өдөөн хатгасан байдлаар

ярьдгийг тэд ойлгодоггүй. Энэ нь яг нарийндаа Бурханы үгийн зорилгын илрэл юм. Бүр эхнээсээ л хүмүүс үргэлж Бурханы үгийг ойлгож ухаарах чадваргүй байсан бөгөөд Түүний айлдварууд үнэндээ нэлээд ноцтой, хатуу юм шиг санагддаг байсан. Бага зэргийн хошигнол нэмж—энд тэнд нь цөөхөн ёгтлол нэмснээрээ Тэр Өөрийнхөө үгээр ярианы өнгийг зөөлрүүлж, булчингаа бага зэрэг суллах боломжийг хүмүүст олгож чаддаг. Ингэснээрээ Тэр бүр ч их үр нөлөөнд хүрч чаддаг ба Бурханы үгийг тунгаан бодуулахаар хүн бүрийг шахдаг.

11-Р БҮЛЭГ

Хүний энгийн нүдээр, энэ хугацаан дахь Бурханы айлдваруудад ямар ч өөрчлөлт гараагүй мэт харагддаг, учир нь хүмүүс Бурханы ярьдаг хуулийг ухаарч чаддаггүй, Түүний үгийн нөхцөл байдлыг ойлгодоггүй. Бурханы үгийг уншсаныхаа дараа хүмүүс эдгээр үгэнд ямар нэг шинэ нууц байгаа гэдэгт итгэдэггүй; тиймээс тэд ер бусын шинэлэг амьдралаар амьдарч чаддаггүй, харин зогсонги, үхээнц амьдралаар амьдардаг. Гэхдээ Бурханы айлдваруудад хүн ойлгохын аргагүй, бас хүрэхийн аргагүй илүү гүнзгий түвшний утга учир байгааг бид хардаг. Өнөөдөр хүн Бурханы ийм үгийг унших хувьтай байгаа нь хамгийн агуу ерөөл юм. Хэрвээ эдгээр үгийг хэн ч уншаагүй бол хүн үүрд биеэ тоосон, өөрийгөө зөвтгөсөн, өөрийгөө мэдэхгүй хэвээр үлдэж, өөрт нь яг хэр олон дутагдал байгааг мэдэхгүй байх байлаа. Бурханы гүн гүнзгий, ойлгохын аргагүй үгийг уншсаныхаа дараа хүмүүс тэдгээрийг нууцхан биширдэг бөгөөд зүрх сэтгэлд нь худал хуурмагтай холилдоогүй жинхэнэ итгэл үнэмшил байдаг; тэдний зүрх сэтгэл хуурамч бараа биш, харин жинхэнэ эд зүйл болдог. Хүмүүсийн зүрх сэтгэлд үнэхээр ийм зүйл тохиолддог. Хүн бүрийн зүрх сэтгэлд өөрийн гэсэн түүх байдаг. Тэд өөрсдөдөө ийнхүү хэлж байгаа юм шиг байдаг: “Үүнийг бараг Бурхан Өөрөө хэлсэн байх—хэрвээ Бурхан биш бол өөр хэн ийм үг айлдаж чадах юм бэ? Би яагаад тэдгээрийг хэлж чаддаггүй юм бэ? Би яагаад тийм ажил хийж чаддаггүй юм бэ? Бурханы ярьдаг бие махбодтой болсон Бурхан үнэхээр бодитой агаад Бурхан Өөрөө юм шиг байна! Би цаашид эргэлзэхгүй. Эс бөгөөс Бурханы гар ирэх үед харамсахад хэтэрхий оройтсон байх юм шиг байна! …” Энэ нь ихэнх хүмүүсийн зүрх сэтгэлдээ боддог зүйл юм. Бурханыг ярьж эхэлсэн үеэс өнөөдрийг хүртэл Бурханы үгийн дэмжлэг байгаагүй бол бүх хүн унах байсан гэдгийг хэлэх нь зүйтэй. Энэ бүх ажлыг хүн биш, Бурхан Өөрөө хийсэн гэж яагаад хэлдэг вэ? Хэрвээ Бурхан чуулганы амьдралыг дэмжихийн тулд үг ашиглаагүй бол хүн бүр ул мөргүй алга болох байв. Энэ нь Бурханы хүч чадал биш гэж үү? Энэ нь үнэхээр хүний цэцэн цэлмэг үг гэж үү? Хүний гайхалтай авьяас уу? Огтхон ч үгүй! Задлан шинжлэхгүйгээр судсаар нь ямар төрлийн цус урсаж байгааг хэн ч мэдэхгүй байх байсан, өөрсдөд нь хэчнээн зүрх байгааг, эсвэл хэдэн тархи байгааг тэд мэдэхгүй байх байсан ба бүгдээрээ

Бурханыг мэддэг гэж бодох байсан юм. Тэдний мэдлэг дотор эсэргүүцэл агуулагдсаар байгаа гэдгийг тэд мэддэггүй гэж үү? Бурхан: “Хүн төрөлхтний хүн болгон Миний Сүнсний шинжилтийг хүлээн авч, өөрсдийн үг, үйлдэл бүрийг сайтар шинжлэх ёстой, түүнчлэн Миний гайхалтай үйл хэргийг харах ёстой” хэмээн хэлсэнд гайхах юмгүй. Бурханы үг зорилгогүй, үндэслэлгүй биш гэдгийг үүнээс харж болно. Бурхан хэзээ ч, хэнд ч шударга бусаар хандаагүй; тийм их итгэлтэй Иов хүртэл үүнээс хэлтрүүлэгдээгүй—тэр бас задлан шинжлүүлж, ичсэндээ нүүр хийх газаргүй үлдсэн юм. Өнөөдрийн хүмүүсийн тухайд бол хэлэхийн ч хэрэггүй. Тиймээс Бурхан: “Хаанчлал газар дээр буун ирэх үед та нарт ямар санагддаг вэ?” гэж даруй асуусан. Бурханы асуулт бага зэрэг л хамаатай боловч хүмүүсийг будилуулж орхидог: “Бидэнд ямар санагддаг вэ? Хаанчлал хэзээ ирэхийг бид одоо ч мэддэггүй, иймээс бид яаж мэдрэмжийн талаар ярьж чадах юм бэ? Үүнээс гадна, бидэнд ямар ч таамаг байхгүй. Хэрвээ би ямар нэг зүйлийг мэдрэх ёстой бол энэ нь өөр юу ч биш, харин ‘мэл гайхах’ явдал байх сан.” Үнэндээ энэ асуулт нь Бурханы үгийн зорилго биш. Юун түрүүнд “Миний хөвгүүд болон ардууд Миний сэнтий рүү цутгах үед агуу цагаан сэнтийн өмнөх шүүлтийг Би албан ёсоор эхлүүлнэ” хэмээх ганц өгүүлбэр бүхий л сүнсний ертөнцийн хөгжил хөдөлгөөнийг нэгтгэн дүгнэдэг. Энэ хугацаанд Бурхан сүнсний ертөнцөд юу хийхийг хүсэж байгааг хэн ч мэддэггүй ба Бурхан эдгээр үгийг айлдсаны дараа л хүмүүст үл ялиг сэхээрэл төрдөг. Бурханы ажилд өөр өөр алхам байдаг учраас бүхий л орчлон ертөнц даяарх Бурханы ажил ч бас ялгаатай байдаг. Энэ хугацаанд Бурхан үндсэндээ Бурханы хөвгүүд болон ардуудыг авардаг, өөрөөр хэлбэл, тэнгэрэлчүүдийн хариулсан Бурханы хөвгүүд болон ардууд харьцалт, эвдэлтийг хүлээн авч эхэлдэг, тэд өөрсдийнхөө бодол болон үзлийг албан ёсоор арилгаж, энэ дэлхийн аливаа ул мөртэй салах ёс хийж эхэлдэг; өөрөөр хэлбэл, Бурханы ярьсан “агуу цагаан сэнтийн өмнөх шүүлт” албан ёсоор эхэлдэг. Энэ нь Бурханы шүүлт учраас Бурхан Өөрийн дуу хоолойг айлдах ёстой—хэдийгээр агуулга нь ялгаатай байдаг ч зорилго нь үргэлж адилхан байдаг. Өнөөдөр Бурханы ярианы өнгөнөөс харвал, Түүний үг тодорхой бүлэг хүмүүс рүү чиглэсэн мэт санагддаг. Үнэндээ юун түрүүнд эдгээр үг бүх хүн төрөлхтний уг чанарт ханддаг. Тэдгээр нь хүний нугас руу шууд нэвтрэн ороод, хүний мэдрэмжүүдийг өршөөдөггүй бөгөөд юу ч орхилгүйгээр, юу ч гаргалгүйгээр түүний мөн чанарыг бүхэлд нь илчилдэг. Өнөөдрөөс эхлээд Бурхан хүний жинхэнэ нүүр царайг албан ёсоор илчилдэг, тийнхүү “Өөрийн Сүнсний дуу хоолойг бүх орчлон ертөнцөд гаргадаг.” Эцэстээ хүрэх үр дүн нь энэ: “Өөрийн үгээр дамжуулан Би тэнгэр газар дахь бүх зүйлийг болон бүх хүнийг цэвэрлэн угаана, ингэснээр газар дэлхий бохир заваан, садар самуун байхаа болиод, харин ариун хаанчлал болно.” Эдгээр үг нь хаанчлалын ирээдүйг буюу Христийн хаанчлалыг бүхэлд нь харуулдаг, яг л Бурханы хэлсэнчлэн “Бүгдээрээ сайн үр жимс, бүгд ажилч хичээнгүй тариаланчид” юм. Энэ нь аяндаа орчлон ертөнц даяар тохиолдох бөгөөд зөвхөн Хятадаар хязгаарлагдахгүй.

Бурханыг ярьж, үйлдэж эхлэх үед л хүмүүс, өөрсдийнхөө үзэлд Түүний талаар бага зэргийн мэдлэгтэй болдог. Анх энэхүү мэдлэг зөвхөн тэдний үзэлд оршдог боловч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүмүүсийн бодол улам бүр хий дэмий, хүмүүс хэрэглэхэд тохиромжгүй болдог; тиймээс тэд “өөрсдийнхөө ухамсарт бодитой Бурханы орон зайг бий болгох” хэмжээнд Бурханы хэлдэг бүхэнд итгэж эхэлдэг. Хүмүүсийн ухамсарт л бодитой Бурханд зориулсан орон зай байдаг. Гэвч, бодит байдал дээр тэд Бурханыг мэддэггүй, дэмий хоосон үг ярихаас өөрийг хийдэггүй. Гэсэн ч өнгөрсөнтэй харьцуулбал тэд асар их ахиц дэвшил гаргасан, гэхдээ бодитой Бурханаас Өөрөөс нь асар их ялгаатай хэвээр байгаа. Яагаад Бурхан үргэлж “Би хүмүүсийн тасралтгүй урсгал дунд өдөр бүр алхаж, өдөр бүр хүн болгоны дотор ажилладаг” гэж хэлдэг вэ? Бурхан иймэрхүү зүйл хэдий чинээ их хэлнэ, хүмүүс тэдгээрийг өнөөдрийн бодитой Бурханы Өөрийн үйлдлүүдтэй төдий чинээ их харьцуулж чадах тул бодитой Бурханыг бодит байдал дээр илүү сайн мэдэж чадна. Бурханы үгийг махбодын өнцгөөс хэлж, хүний хэлийг ашиглан айлддаг учраас тэдгээрийг материаллаг зүйлтэй харьцуулснаар хүмүүс Бурханы үгийг ойлгож, улмаар илүү их үр дүнд хүрч чаддаг. Үүнээс гадна Бурхан хүмүүсийн зүрх сэтгэл дэх “Би” болон бодит байдал дээрх “Би”-гийн дүр төрхийн талаар ахин дахин ярьдаг, ингэснээр хүмүүс өөрсдийнхөө зүрх сэтгэл дэх Бурханы дүрийг арилгахыг илүү их хүсэж, тийнхүү бодитой Бурханыг Өөрийг нь мэдэж, Түүнтэй харилцахад бэлэн болдог. Энэ нь Бурханы үгийн мэргэн ухаан билээ. Бурхан ийм зүйлсийг хэлэх тусам, Бурханы талаарх хүмүүсийн мэдлэгт төдий чинээ их ашиг тустай байдаг, тиймээс Бурхан: “Хэрвээ Би махбод болоогүй бол хүн хэзээ ч Намайг мэдэхгүй байх байсан бөгөөд Намайг мэдэж авсан ч гэсэн тийм мэдлэг нь мөн л үзэл байх бус уу?” хэмээн хэлсэн. Үнэндээ, өөрсдийнхөө үзлийн дагуу Бурханыг мэдэхийг хүмүүсээс шаардсан бол энэ нь тэдний хувьд амархан байх байсан; тэд тайван, аз жаргалтай байж, улмаар Бурхан хүмүүсийн зүрх сэтгэлд үүрд тодорхойгүй, бодитой бус байх байв, энэ нь Бурхан биш Сатан бүхий л орчлон ертөнцийг ноёрхдог гэдгийг нотлох байсан; тиймээс “Би эрх мэдлээ буцаан авсан” хэмээх Бурханы үг үүрд хий хоосон хэвээр үлдэх байлаа.

Бурханлаг чанар шууд үйлдэж эхлэх үе нь бас хаанчлал албан ёсоор хүний ертөнцөд бууж ирэх цаг юм. Гэхдээ хаанчлал хүмүүсийн дунд хэлбэрээ олохыг биш, харин хүмүүсийн дунд бууж ирэхийг энд хэлсэн—тиймээс өнөөдрийн ярьсан зүйл нь хаанчлал хэрхэн хэлбэрээ олох тухай биш, харин хаанчлалын бүтээн байгуулалт юм. Яагаад Бурхан “Бүх зүйл чимээгүй болдог” гэж үргэлж хэлдэг вэ? Бүх зүйл анир чимээгүй болох юм гэж үү? Өндөр уулс үнэхээр чимээгүй болох юм гэж үү? Тэгвэл яагаад хүмүүс үүнийг огт мэдэрдэггүй юм бэ? Бурханы үг буруу юм гэж үү? Эсвэл Бурхан хэтрүүлж байгаа юм уу? Бурханы хийдэг бүхэн тодорхой орчинд явагддаг учраас хэн ч үүнийг мэддэггүй, эсвэл үүнийг нүдээрээ харж чаддаггүй бөгөөд хүмүүс Бурханы ярихыг сонсож л чадна. Бурханы үйлддэг сүр жавхлангаас болоод Бурханыг ирэх үед тэнгэр, газарт асар их өөрчлөлт гарсан мэт

байдаг; Бурханы хувьд бүх хүн энэ мөчийг ажиглаж байгаа мэт харагддаг. Өнөөдөр баримтууд хараахан гарч ирээгүй байгаа. Хүмүүс ердөө Бурханы үгийн үгчилсэн утгын зарим хэсгийг бага зэрэг мэдэж авсан. Тэд өөрсдийнхөө үзлийг арилгах үеийг л жинхэнэ утга нь хүлээж байдаг; тэр үед л тэд бие махбодтой болсон Бурхан өнөөдөр газар дээр болон тэнгэрт юу хийж байгааг мэдэж авна. Хятад дахь Бурханы ардуудад зөвхөн агуу улаан лууны хор байгаа юм биш. Иймээс тэдэнд бас агуу улаан лууны уг чанар илүү ихээр, илүү тодорхой илчлэгддэг. Гэхдээ Бурхан энэ талаар шууд ярьдаггүй, ердөө агуу улаан лууны хорын талаар бага зэрэг дурддаг. Ийм маягаар Тэр хүний шархыг шууд ил болгодоггүй нь хүний ахиц дэвшилд илүү их ач тустай байдаг. Агуу улаан лууны үр сад, бусдын өмнө агуу улаан лууны үр удам гэж нэрлэгдэх дургүй байдаг. “Агуу улаан луу” хэмээх үг тэдэнд ичгүүр авчирдаг мэт байдаг; тэдний хэн нь ч эдгээр үгийг хэлэхийг хүсдэггүй, тиймээс Бурхан: “Миний ажлын энэ үе шат голчлон та нар дээр төвлөрдөг, энэ нь Хятадад бие махбодтой болсны минь ач холбогдлын нэг тал юм” гэж л хэлдэг. Илүү нарийн хэлбэл, Бурхан агуу улаан лууны үр садын ердийн төлөөлөгчдийг байлдан дагуулахын тулд үндсэндээ ирсэн ба энэ нь Бурхан Хятадад бие махбодтой болсны утга учир юм.

“Намайг хүмүүсийн дунд биечлэн ирэхэд тэнгэрэлчүүд хариулах ажлаа нэгэн зэрэг эхэлдэг.” Үнэндээ, тэнгэрэлчүүд бүх хүний дунд ажлаа эхлүүлэх үед л Бурханы Сүнс хүний ертөнцөд ирдэг гэдгийг үгчлэн хэлээгүй. Харин, энэ хоёр ажил буюу бурханлаг чанарын ажил болон тэнгэрэлчүүдийн хариулга нь нэгэн зэрэг гүйцэтгэгддэг. Дараа нь Бурхан, тэнгэрэлчүүдийн хариулгын талаар бага зэрэг ярьсан. Түүнийг “хөвгүүд болон ардууд бүгд шалгалт, хариулгыг хүлээн аваад зогсохгүй, төрөл бүрийн үзэгдэл тохиолдохыг өөрсдийн нүдээр харж чаддаг” гэж хэлэх үед ихэнх хүмүүс “үзэгдэл” хэмээх үгийн талаар асар их төсөөлөлтэй байдаг. Үзэгдэл гэдэг нь хүмүүсийн төсөөлөл дэх ер бусын үйл явдлуудыг хэлдэг. Гэхдээ ажлын агуулга нь бодитой Бурханыг Өөрийг нь мэдэх явдал хэвээр үлддэг. Үзэгдлүүд бол тэнгэрэлчүүдийн ажилладаг арга барил юм. Тэдгээр нь хүмүүст мэдрэмж юм уу зүүд өгч, тэнгэрэлчүүдийн оршин тогтнолыг ухамсарлуулж магадгүй. Гэхдээ тэнгэрэлчүүд хүнд харагдахгүй хэвээр үлддэг. Бурханы хөвгүүд, ардуудын дунд тэдний ажилладаг арга барил нь тэднийг шууд гэгээрүүлж, гэрэлтүүлэх, үүн дээр нэмээд тэдэнтэй харьцаж, тэднийг эвдэх явдал юм. Тэд хааяахан номлодог. Угаасаа хүмүүсийн хоорондох яриа бол тусдаа хэрэг; энэ нь Хятадын гаднах улс орнуудад тохиолдож байгаа зүйл. Бурханы үгэн дотор агуулагддаг зүйл нь бүх хүн төрөлхтний амьдралын нөхцөл байдлын илчлэл юм—мэдээжийн хэрэг энэ нь үндсэндээ агуу улаан лууны үр сад руу чиглэдэг. Бүх хүн төрөлхтний янз бүрийн байр байдлаас Бурхан үлгэр дуурайл болон үйлчлэх төлөөлөгчдийг сонгодог. Тиймээс Бурханы үг хүмүүсийг нүцгэлдэг ба тэд ямар ч ичгүүр сонжуургүй байдаг, аль эсвэл цацрах гэрлээс нуугдах цаг завгүйгээр, өөрсдийнхөө тоглоомд ялагддаг. Хүний олон ааш маяг бол асар олон тооны дүр

зураг бөгөөд Бурхан үүнийг балар эртний үеэс өнөөдрийг хүртэл зурсан, мөн үүнийг Тэр өнөөдрөөс эхлээд маргаашийг хүртэл зурна. Түүний зурдаг бүхэн нь хүний муу муухай байдал: Зарим нь харанхуйд уйлж, нүд нь сохорсонд илт энэлэн шаналж байх шиг байдаг, зарим нь инээж, зарим нь том давлагаанд цохигдож, зарим нь овон товонтой уулын замаар алхаж, зарим нь өргөн уудам цөлийн дунд юм хайж, нумын хөвч татах төдийд цочдог шувуу адил айн чичирч, уулын зэрлэг амьтдад идүүлэхээс ихэд айж байдаг. Бурханы гарт энэ олон муухай ааш маяг нь сэтгэл хөдлөм, амьд мэт зураг болдог, тэдгээрийн дийлэнх нь харахад хэтэрхий аймшигтай, эсвэл хүмүүсийн толгойтой үсийг босгож, тэднийг төөрөлдүүлж, будилуулж орхиход хангалттай. Бурханы нүдээр бол хүнээс харагддаг бүхэн нь гагцхүү муу муухай байдал бөгөөд хэдийгээр өрөвдөх сэтгэл төрүүлдэг боловч энэ нь муу муухай байдал хэвээр юм. Хүн Бурхан хоёрын гол ялгаа гэвэл, хүний сул тал нь бусдад нинжин сэтгэл харуулах хандлагатай байдагт оршино. Гэтэл Бурхан хүнд үргэлж нэгэн ижил хандсан, энэ нь Тэр үргэлж нэгэн ижил хандлагатай байсан гэсэн үг юм. Тэрээр хүмүүсийн төсөөлдгөөр хүүхдүүдээ дандаа эхэнд тавьдаг туршлагатай ээж шиг үргэлж сайхан сэтгэлтэй байдаггүй. Бодит байдал дээр, хэрвээ Бурхан агуу улаан лууг байлдан дагуулахын тулд иж бүрэн арга барил ашиглахыг хүсээгүй бол ийм доромжлолд өртөж, хүний хязгаарлалтад автахгүй байх байсан юм. Бурханы зан чанарын дагуу, хүмүүсийн хийдэг, хэлдэг бүхэн Бурханы уур хилэнг өдөөдөг ба тэд гэсгээгдэх учиртай. Бурханы нүдээр тэдний нэг нь ч стандартад нийцдэггүй бөгөөд бүгдээрээ Бурханаар цохиулах хүмүүс юм. Хятад дахь Бурханы ажлын зарчмуудаас болж, түүнчлэн агуу улаан лууны уг чанараас болж, дээр нь нэмээд Хятад бол агуу улаан лууны улс орон, бие махбодтой болсон Бурханы оршин суудаг газар нутаг хэмээх баримтаас болж Бурхан уураа дарж, агуу улаан лууны бүх үр садыг байлдан дагуулах ёстой; гэсэн ч Тэр агуу улаан лууны үр садыг үргэлж жигшинэ, өөрөөр хэлбэл, агуу улаан луунаас гардаг бүхнийг үргэлж жигшинэ—энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй.

Хэн ч хэзээ ч Бурханы үйлдлийн талаар мэдэж байгаагүй, мөн хэзээ ч юу ч Түүний үйлдлүүдийг харж байгаагүй. Жишээлбэл, Бурханыг Сионд буцан ирэх үед хэн энэ талаар мэдсэн бэ? Тиймээс “Би хүмүүсийн дунд чимээгүй ирж, дараа нь хөвөн оддог. Хэн ер нь Намайг харсан юм бэ?” хэмээх үгс нь хүнд үнэндээ сүнсний ертөнцийн үйл явдлуудыг хүлээн авах эрхтэн байхгүй гэдгийг харуулдаг. Түүнийг Сион руу эргэн ирэх үед “нар төөнөж, сар гэрэлтсэн” байдаг гэж Бурхан урьд нь хэлсэн. Хүмүүс Бурхан Сионд эргэн ирэх талаар санаа тавьсаар байгаа учраас—үүнийг хараахан орхиогүй учраас—хүмүүсийн үзэлд нийцүүлэхийн тулд Бурхан “нар төөнөж, сар гэрэлтсэн” гэх үгийг шууд айлддаг. Үүний үр дүнд, хүмүүсийн үзлийг Бурханы үг цохих үед тэд Бурханы үйлдлүүд маш гайхалтай гэдгийг харж, Түүний үг гүн гүнзгий агаад бүх хүний хувьд ойлгохын аргагүй, тайлахын аргагүй гэдгийг хардаг; тиймээс тэд энэ хэрэг явдлыг бүрмөсөн хойш тавьж, Бурхан аль хэдийн Сионд эргэн ирсэн мэт сүнсэндээ бага зэрэг тодорхой байдлыг мэдэрдэг

тул энэ хэрэг явдалд асар их анхаарал хандуулдаггүй. Энэ мөчөөс эхлээд тэд Бурханы үгийг нэгэн зүрх сэтгэл, нэгэн оюун ухаанаар хүлээн авч, Бурханыг Сионд буцан ирсний дараа гамшиг тохиолдох болно гэж түгшихээ больдог. Зөвхөн тэр үед л Бурханы үгийг хүлээн авч, хамаг анхаарлаа Бурханы үгэнд хандуулах нь хүмүүст амархан байх ба тэд өөр юуг ч анхаарах хүсэлгүй болдог.

НЭМЭЛТ
2-Р БҮЛЭГ

Хүмүүс бодитой Бурханыг харах үедээ, мөн Бурхантай Өөртэй нь биечлэн хамт амьдарч, мөр зэрэгцэн алхаж, хамт оршин суух үедээ зүрх сэтгэлдээ маш олон жилийн турш тээж байсан сониуч зангаа хойш тавьдаг. Урьд нь ярьсан Бурханы тухай мэдлэг бол зөвхөн эхний алхам юм; хэдийгээр хүмүүс Бурханы тухай мэдлэгтэй байдаг ч зүрх сэтгэлд нь байнгын олон эргэлзээ үлдсэн: Бурхан хаанаас ирсэн юм бэ? Бурхан юм иддэг үү? Бурхан эгэл хүмүүсээс асар өөр үү? Бурханы хувьд бүх хүнтэй харьцах нь маш амархан, туйлын энгийн хэрэг үү? Бурханы хэлсэн бүхэн нь тэнгэрийн нууцууд уу? Түүний хэлдэг бүхэн нь бүтээгдсэн бүх зүйлийн хэлснээс илүү өндөр үү? Бурханы нүднээс гэрэл цацардаг уу? Гэх мэт—хүмүүсийн үзэл ийм чадвартай байдаг. Эдгээр зүйл бол юун түрүүнд ойлгож, орох ёстой зүйл чинь юм. Хүмүүсийн үзлээр, бие махбодтой болсон Бурхан нь тодорхойгүй Бурхан хэвээр байдаг. Бодитой мэдлэгээр л дамжихгүй бол хүмүүс хэзээ ч Намайг ойлгож чадахгүй, өөрсдийн туршлагаар Миний үйл хэргийг хэзээ ч харахгүй байх байлаа. Би махбод болсон учраас л хүмүүс Миний хүслийг “ухаарч чадахгүй” байгаа юм. Хэрвээ Би махбод бололгүй, тэнгэрт, сүнсний ертөнцөд байсаар байсан бол хүмүүс Намайг “мэдэх” байсан; тэд Надад сөгдөж, шүтэн мөргөөд, өөрсдийн туршлагаас Миний тухай “мэдлэгээ” ярих байсан—гэвч тийм мэдлэг ямар хэрэгтэй юм бэ? Лавлагаа болохын хувьд үнэ цэн нь ямар байх вэ? Хүмүүсийн үзлээс гарч ирдэг мэдлэг бодитой байж чадна гэж үү? Би хүмүүсийн уураг тархины мэдлэгийг хүсдэггүй—харин бодитой мэдлэгийг хүсдэг.

Миний хүсэл та нарын дунд цаг ямагт илчлэгддэг ба Миний гэрэлтүүлэлт болон гэгээрэл цаг үргэлж байдаг. Намайг шууд бурханлаг чанараар үйлдэх үед энэ нь уураг тархиар шүүгддэггүй, ямар ч “амтлагч” нэмэх хэрэггүй байдаг—энэ нь бурханлаг чанараар шууд хийгддэг. Хүмүүс ямар чадвартай вэ? Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Би бүхнийг биечлэн гүйцэтгэсэн бус уу? Өмнө нь Би долоо дахин эрчимжсэн Сүнсний тухай ярьсан боловч хэн ч Түүний мөн чанарыг ойлгож чадаагүй—тэд үүнийг мэдэж байх үедээ ч гэсэн бүрэн гүйцэд ойлгох чадваргүй байсан юм. Намайг бурханлаг чанарт захирагдсан хүн чанараар ажиллах үед энэхүү ажил нь хүмүүсийн ер бусын биш, харин хэвийн гэж үздэг нөхцөл байдалд явагддаг учраас үүнийг Ариун Сүнсний ажил гэж нэрлэдэг. Бурханлаг чанараар

шууд ажиллах үедээ Би хүмүүсийн үзлээр хязгаарлагддаггүй, мөн тэдний үзэлд оршдог “ер бусын” хязгаарт захирагддаггүй учраас энэхүү ажил хурдан үр дүнтэй байдаг; энэ нь хэрэг явдлын гол цөмд хүрч, гол зүйлдээ шууд ордог. Үүний үрээр ажлын энэхүү алхам илүү цэвэр; хоёр дахин хурдан байдаг ба хүмүүсийн ойлголт хурдсаж, Миний үг ихсэж, бүх хүнийг хөл нийлүүлэхээр яаравчлахад хүргэдэг. Үр нөлөө нь өөр учраас, мөн Миний ажлын арга барил, шинж чанар, агуулга адилхан биш учраас—түүнчлэн Би албан ёсоор махбодоор ажиллаж эхэлсэн учраас дээр дурдсаныг харгалзан үзээд ажлын энэхүү алхмыг “долоо дахин эрчимжсэн Сүнсний ажил” гэж хэлж болно. Энэ нь хийсвэр зүйл биш. Та нар дээр Миний ажилладаг арга барил хөгжихийг дагаад, мөн хаанчлалын ирэлтийг дагаад долоо дахин эрчимжсэн Сүнс ажиллаж эхэлдэг бөгөөд энэхүү ажил байнга гүнзгийрч, эрчимжиж байдаг. Бүх хүн Бурханыг харж, Бурханы Сүнс хүмүүсийн дунд байгааг бүгдээрээ харах үед бие махбодтой болсны минь бүхий л ач холбогдол тодорхой болдог. Үүнийг нэгтгэн дүгнэх хэрэггүй, харин хүмүүс аяндаа мэддэг.

Өнөөдөр Миний ажилладаг арга барил, Миний ажлын алхмууд, Миний үгийн өнгө гэх мэт олон талыг бодолцон үзвэл одоо Миний амнаас гарч байгаа зүйл л жинхэнэ утгаараа “долоон Сүнсний айлдварууд” юм. Хэдийгээр Би бас урьд нь үг хэлж байсан ч тэр нь чуулганыг барьж байгуулах үе шатанд болсон. Энэ нь романы удиртгал болон гарчигтай адилхан, мөн чанаргүй байсан юм; жинхэнэ мөн чанарынх нь хувьд зөвхөн өнөөдрийн айлдваруудыг л долоон Сүнсний айлдварууд гэж нэрлэж болно. “Долоон Сүнсний айлдварууд” гэж сэнтийнээс гардаг айлдваруудыг хэлдэг, өөрөөр хэлбэл, тэдгээрийг шууд бурханлаг чанараар айлддаг юм. Миний айлдварууд тэнгэрийн нууцуудыг илчилж эхэлсэн үе бол Би шууд бурханлаг чанараар ярьсан үе байлаа. Өөрөөр хэлбэл, Би хүн чанарт хязгаарлагдалгүйгээр сүнсний ертөнцийн бүх нууц болон нөхцөл байдлыг шууд илчилсэн. Урьд нь хүн чанарын хязгаарт захирагдаж байсан гэж Би яагаад хэлдэг вэ? Үүнд тайлбар шаардлагатай. Хүмүүсийн нүдээр бол хэн ч тэнгэрийн нууцуудыг илчлэх чадваргүй; Бурхан Өөрөө байгаагүй бол газар дээрх хэн ч эдгээр нууцын талаар мэдэж чадахгүй. Тиймээс Би хүмүүсийн үзэлд хандаж үгээ хэлдэг ба Би хүн чанарын хязгаарт захирагддаг байсан учраас өнгөрсөн үед ямар ч нууцыг илчлээгүй гэж хэлдэг. Гэхдээ илүү тодорхой хэлбэл ийм биш: Миний ажил өөр байдгаас болж Миний үгийн агуулга өөр байдаг, тиймээс бурханлаг чанараар Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхлэх үедээ Би нууцуудыг илчилсэн; өнгөрсөн үед Би бүх хүний хэвийн гэж үздэг нөхцөл байдалд ажиллах хэрэгтэй байсан ба Миний хэлсэн үг хүмүүсийн үзэлд биелэх чадвартай байлаа. Намайг нууцуудыг илчилж эхлэх үед хүмүүсийн үзлээр бол эдгээрийн нэг нь ч хүршгүй байсан юм—тэдгээр нь хүний сэтгэлгээтэй адилгүй байв. Иймээс Би албан ёсоор бурханлаг чанараар үгээ хэлж эхэлсэн бөгөөд эдгээр нь жинхэнэ утгаараа долоон Сүнсний айлдварууд байлаа. Хэдийгээр урьдын үг нь сэнтийнээс гарсан айлдварууд байсан боловч тэдгээрийг хүмүүсийн хүрэх боломжтой зүйлсийн үндсэн дээр хэлсэн, тиймээс бурханлаг чанараар шууд

айлдаагүй юм—үүний үр дүнд тэдгээр нь жинхэнэ утгаараа долоон Сүнсний айлдварууд байгаагүй билээ.

12-Р БҮЛЭГ

Бүх хүн анхааралтай байж, бүх зүйл шинэчлэгдэн сэргэж, хүн бүр эргэлзэлгүйгээр Бурханд захирагдаж, Бурханы ачааны хүнд хариуцлагыг үүрэхэд бэлэн байх үе нь зүүний аянга цахиж, зүүнээс баруун зүгт байгаа бүхнийг гэрэлтүүлж, энэхүү гэрлийн ирэлтээр газар дэлхийн бүх хүнийг айлгах үе юм; энэ мөчид Бурхан дахин нэгэнтээ шинэ амьдралыг эхэлдэг. Өөрөөр хэлбэл, энэ мөчид Бурхан газар дээр шинэ ажил эхлүүлж, бүхий л орчлон ертөнцийн хүмүүст “аянга зүүн зүгээс цахих үе нь бас Би үгээ айлдаж эхлэх яг тэр мөч бөгөөд—аянга цахих үед бүхий л орчлон ертөнц гэрэлтэж, бүх од хувирдаг” хэмээн тунхагладаг. Тэгвэл аянга зүүн зүгээс цахих үе нь хэзээ юм бэ? Тэнгэр харанхуйлж, газар дэлхий сүүмийх үе нь Бурхан Өөрийн царайг дэлхий ертөнцөөс нуух үе бөгөөд энэ нь тэнгэрийн доорх бүхэн хүчит шуургатай тулгарах гэж буй яг тэр мөч юм. Гэхдээ энэ удаа бүх хүн цочирдож, тэнгэрийн дуунаас эмээж, аянгын гялбаанаас айж, ширүүн аадар бороноос бүр ч их айдаг, тийм болохоор тэдний ихэнх нь нүдээ аниад, Бурхан уур хилэнгээ гаргаж, өөрсдийг нь цохин унагахыг хүлээдэг. Янз бүрийн нөхцөл байдал тохиолдоход зүүний аянга нэн даруй цахилдаг. Өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн гэрчлэл эхлэх үед, Түүнийг ажиллаж эхлэх үед, бурханлаг чанар газар дэлхий даяар бүрэн эрх мэдлийг эзэмшиж эхлэх үед дэлхий ертөнцийн зүүн зүгт—бүхий л орчлон ертөнцөд мөнхөд гэрэлтсэн, зүүний аянгын гялалзсан цацраг байдаг. Газар дэлхийн улс орнууд Христийн хаанчлал болох үе нь бүхий л орчлон ертөнц гэрэлтүүлэгдэх үе билээ. Одоо үе бол зүүний аянга цахих үе. Бие махбодтой болсон Бурхан ажиллаж эхэлдэг, түүнчлэн бурханлаг чанараар шууд ярьдаг. Бурхан газар дээр үг хэлж эхлэх үе нь зүүний аянга цахих үе юм гэж хэлж болно. Илүү тодорхой хэлбэл, амийн ус сэнтийнээс урсах үе—сэнтийнээс гарах айлдварууд эхлэх үе нь—яг нарийндаа долоон Сүнсний айлдварууд албан ёсоор эхлэх үе юм. Энэ үед зүүний аянга цахиж эхэлдэг ба үргэлжлэх хугацаанаасаа үүдэн гэрэлтүүлэлтийн түвшин ч бас ялгаатай байдаг, мөн гэрлийн цар хүрээ нь ч гэсэн хязгаартай байдаг. Гэхдээ Бурханы ажил шилжиж, Түүний төлөвлөгөө өөрчлөгдөхөд—Бурханы хөвгүүд болон ардууд дахь ажил өөрчлөгдөхөд—аянга төрөлхийн чиг үүргээ улам их гүйцэтгэн, тэгснээр орчлон ертөнц даяар гэрэлтэж, ямар ч шаар шавхруу, эсвэл хог хаягдал үлддэггүй. Энэ бол Бурханы 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөний биелэлт, Бурханы эдэлдэг яг тэр үр жимс билээ. “Одод” гэдэг нь тэнгэр дэх оддыг хэлдэггүй, харин Бурханы төлөө ажилладаг Бурханы бүх хөвгүүд болон ардыг хэлдэг. Тэд Бурханы хаанчлалд Бурханд гэрчлэл хийж, Бурханы хаанчлалд Бурханыг төлөөлдөг учраас, мөн тэд бүтээлүүд учраас тэднийг “одод” гэж нэрлэдэг. “Хувирах” гэдэг нь

ялгамж чанар болон байр суурийн өөрчлөлтийг хэлдэг: Тэд газар дээрх хүмүүс байснаа хаанчлалын ардууд болж өөрчлөгддөг ба түүнчлэн Бурхан тэдэнтэй хамт байж, Бурханы алдар тэдэнтэй хамт байдаг. Үүний үр дүнд тэд Бурханы оронд бүрэн эрх мэдлийг эзэмшдэг бөгөөд тэдний доторх хор болон хольц Бурханы ажлаар цэвэрлэгдэн, эцэстээ тэд Бурханаар ашиглагдахад тохиромжтой, Бурханы зүрх сэтгэлийн дагуу болдог—энэ нь эдгээр үгийн утга учрын нэг тал юм. Бурханаас гарсан гэрлийн цацраг газар нутгийг бүхэлд нь гэрэлтүүлэх үед тэнгэр, газар дахь бүх зүйл янз бүрийн түвшинд өөрчлөгдөж, тэнгэр дэх одод ч бас өөрчлөгдөж, нар сар шинэчлэгдэнэ, дараа нь газар дээрх хүмүүс ч бас шинэчлэгдэнэ—энэ нь тэнгэр, газрын хооронд Бурханы хийсэн ажил бөгөөд гайхах зүйлгүй.

Бурхан хүмүүсийг аврах үе нь мэдээж сонгогдоогүй хүмүүсийг хэлдэггүй ба энэ нь, Бурхан хүмүүсийг цэвэрлэн шүүж, бүх хүн Бурханы үгээс болж гашуунаар уйлж, эсвэл орон дээрээ унаж, эсвэл доош цохигдон, үхлийн там руу унадаг яг тэр үе юм. Бурханы айлдваруудын ачаар л хүмүүс өөрсдийгөө мэдэж эхэлдэг. Тэгээгүй бол тэд бах мэлхийн нүдтэй буюу—дээшээ харсан, хэнд ч үнэмшээгүй, хэн нь ч өөрийгөө мэдэхгүй, хэдэн чулууны жинтэйгээ ч мэдэхгүй байх байлаа. Сатан хүмүүсийг үнэхээр асар их завхруулсан. Бурханы бүхнийг чадагч байдлаас л үүдэн хүний муухай төрх тийм тод томруун дүрслэгдсэн ба үүнийг уншсаныхаа дараа өөрийнхөө жинхэнэ төрхтэй харьцуулахад хүнийг хүргэдэг. Хүмүүсийн толгойд уураг тархины хэдэн эс байгааг Бурхан тов тодорхой мэддэг мэт санагддаг ба тэдний муухай төрх, эсвэл сэтгэлийн гүн дэх бодлын талаар ярихын ч хэрэггүй гэдгийг хүмүүс бүгд мэднэ. “Бүх хүн төрөлхтөн ангилагдсан мэт байдаг. Зүүн зүгийн гэрлийн энэхүү цацрагийн туяан дор бүх хүн төрөлхтний анхдагч төрх илчлэгдэж, нүд нь гялбаж, яахаа мэддэггүй” хэмээх үгээс нэг л өдөр Бурханы ажил дуусах үед бүх хүн төрөлхтнийг Бурхан шүүнэ гэдгийг харж болно. Ганц ч хүн зугтаж чадахгүй; Бурхан бүх хүн төрөлхтнөөс нэгийг нь ч орхигдуулахгүйгээр нэг бүрчлэн зохицуулах бөгөөд тэгж байж л Бурханы сэтгэл ханана. Иймээс Бурхан: “Тэд бас Миний гэрлээс зугтан уулын агуй руу дүрвэж байгаа амьтадтай адил байдаг—гэхдээ тэдний дундаас хэн нь ч Миний гэрэл дотроос арчигдан арилж чадахгүй” гэж хэлдэг. Хүмүүс бол дорд, муу амьтад. Сатаны гарт амьдарч байж уулын гүнд орших эртний ой шугуйд хоргодсон мэт байдаг—гэхдээ Бурханы галд шатахаас юу ч зайлсхийж чадахгүй, Сатаны хүчний “хамгаалалт” дор байхад нь ч гэсэн Бурхан яаж тэднийг мартах юм бэ? Хүмүүс Бурханы үгийн ирэлтийг хүлээн авах үед бүх хүний янз бүрийн этгээд төрх болон хөгийн байдлыг Бурханы үзэг дүрсэлдэг; Бурхан хүний хэрэгцээ болон сэтгэхүйд тохируулан ярьдаг. Тиймээс хүмүүст Бурхан сэтгэл зүйг сайн мэддэг мэт харагддаг. Бурхан сэтгэл зүйч шиг байдаг боловч бас дотрын нарийн мэргэжлийн эмч шиг байдаг—Тэрээр “ярвигтай” хүний талаар тийм ойлголттой байдагт гайхах юмгүй. Хүмүүс ингэж бодох тусам, Бурханы эрхэм нандин байдлын талаарх мэдрэмж нь төдий чинээ их байдаг ба Бурхан бол гүн гүнзгий агаад ойлгошгүй гэдгийг төдий чинээ их мэдэрдэг. Хүн, Бурхан хоёрын

хооронд туулахын аргагүй огторгуйн хил хязгаар байдаг мэт боловч бас энэ хоёр бие биеэ Чу голын[a] хоёр эргээс харж, нэг нэгнээ харахаас өөрийг хийж чадахгүй байгаа мэт байдаг. Өөрөөр хэлбэл, газар дээрх хүмүүс Бурханыг нүдээрээ л хардаг; тэдэнд Бурханыг ойроос судлах боломж хэзээ ч байгаагүй, Түүнд сэтгэл татагдах мэдрэмж л тэдэнд байдаг. Тэдний зүрх сэтгэлд Бурхан бол хайр татам гэсэн мэдрэмж үргэлж байдаг боловч Бурхан тун “цэвдэг, хатуу сэтгэлтэй” болохоор өөрсдийн зүрх сэтгэл дэх шаналал зовлонгийнхоо талаар Түүний өмнө ярих боломж тэдэнд хэзээ ч олдоогүй. Тэд, нөхрийнхөө шударга зангаас болж өөрийнхөө жинхэнэ мэдрэмжийг хэлэх боломж хэзээ ч олдоогүй, нөхрийнхөө өмнө байгаа үзэсгэлэнтэй залуу эхнэр шиг байдаг. Хүмүүс бол өөрсдийгөө үзэн яддаг өөдгүй амьтад тул тэдний сул доройгоос болж, өөрсдийгөө хүндлэх хүндлэл дутмагаас болж хүнд хандах Миний үзэн ядалт өөрийн эрхгүй үл ялиг ихэссэн бөгөөд Миний зүрх сэтгэл доторх уур хилэн оргилон гарсан. Оюун санаандаа Би гэмтэл авсан мэт байдаг. Би аль хэдийн хүнд тавих найдвараа алдсан, гэхдээ “Миний өдөр дахин нэг удаа хүн төрөлхтөнд ойртож ирэн, хүн төрөлхтнийг дахин нэгэнтээ сэрээж, хүн төрөлхтөнд шинээр эхлэх цэгийг өгсөн” учраас Би бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, агуу улаан лууг олзлон авч, ялан дийлэхээр дахин нэгэнтээ зориглосон. Бурханы анхдагч санаа зорилго нь Хятад дахь агуу улаан лууны үр садыг л байлдан дагуулах явдал байсан; зөвхөн үүнийг л агуу улаан лууны ялагдал, агуу улаан лууг эрхэндээ оруулах явдал гэж үзэж болно. Бурханы агуу ажлын амжилтыг батлан Бурхан газар дэлхий даяар Хаан болж хаанчилдаг бөгөөд Бурхан газар дээр шинээр эхэлж, газар дээр алдрыг олж авсан гэдгийг батлахад зөвхөн энэ л хангалттай. Эцсийн үзэсгэлэнтэй сайхан дүр зургаас болж Бурхан Өөрийн зүрх сэтгэл дэх хүсэл тэмүүллийг өөрийн эрхгүй илэрхийлдэг: “Миний зүрх цохилж, Миний зүрхний цохилтыг дагаад уулс баяртайгаар дэвхэрч, ус баярлан бүжиж, давлагаа хадан цохио мөргөнө. Миний зүрх сэтгэлд юу байгааг илэрхийлэхэд хэцүү.” Бурханы төлөвлөсөн зүйл бол Түүний аль хэдийн гүйцэлдүүлсэн зүйл; энэ нь Бурханы урьдчилан тодорхойлсон, чухамдаа хүмүүст мэдрүүлж, харуулдаг зүйл нь юм гэдгийг үүнээс харж болно. Хаанчлалын хэтийн ирээдүй үзэсгэлэнтэй сайхан; хаанчлалын Хаан бол ялагч бөгөөд толгойноос нь хөл хүртэл мах, цусны ямар ч ул мөр байхгүй, бүхэлдээ бурханлаг элементээс бүрдсэн байдаг. Түүний бүхий л бие хүний санаагаар огт сэвтэлгүйгээр ариун дагшин алдраар гэрэлтдэг; Түүний бүхий л бие хөлөөсөө толгой хүртэл зөвт байдал болон тэнгэрийн аурагаар бялхаж, таатай үнэр ханхлуулдаг. Соломоны дуунд гардаг хайртын адилаар Тэрээр бүх ариун хүнээс илүү үзэсгэлэнтэй, эртний ариун хүмүүсээс илүү өндөр дээд; бүх хүний дундах үлгэр дуурайл бөгөөд хүнтэй харьцуулшгүй; хүмүүс Түүн рүү шууд харахад тохирохгүй. Хэн ч Бурханы алдар суут царай төрх, Бурханы харагдах байдал, эсвэл Бурханы дүрд хүрч чадахгүй; хэн

[a] “Чу гол” гэдэг нь эсрэг хоёр хүчний хоорондох хил хязгаарыг зүйрлэн хэлдэг.

ч тэдгээртэй өрсөлдөж чадахгүй, мөн хэн ч тэдгээрийг өөрсдийн амаар хялбархан магтаж чадахгүй.

Бурханы үгэнд эцэс төгсгөл үгүй—булгаас урсаж буй ус мэт хэзээ ч хатаж ширгэхгүй тул Бурханы удирдлагын төлөвлөгөөний нууцыг хэн ч ухан ойлгож чадахгүй. Гэхдээ Бурханы хувьд тийм нууцууд нь дуусашгүй. Өөр өөр арга барил болон хэлийг ашиглан, Бурхан бүхий л орчлон ертөнцийг шинэчилж, бүрмөсөн хувиргаж байгаа талаараа олон удаа ярьсан ба тухай бүр нь өмнөхөөсөө илүү гүн гүнзгий байдаг: “Би бүх бохир зүйлийг Өөрийн харцны дор үнс нурам болтол шатаахыг хүсдэг; бүх дуулгаваргүй хөвгүүдийг дахин хэзээ ч оршин тогтнуулалгүй, нүднийхээ өмнөөс арилгахыг хүсдэг.” Яагаад Бурхан ийм зүйлсийг удаа дараа хэлдэг вэ? Тэр хүмүүсийг залхаахаас айхгүй байна гэж үү? Хүмүүс зүгээр л Бурханы үгэн дунд тэмтчин явж, Бурханыг ийм маягаар мэдэхийг хүсдэг боловч өөрсдийгөө шалгаж шинжлэхээ хэзээ ч санадаггүй. Тиймээс Бурхан тэдэнд сануулж, тэдэнд бүгдэд нь өөрсдийг нь мэдүүлэхийн тулд энэ арга барилыг ашигладаг, ингэснээр тэд өөрсдөөсөө хүний дуулгаваргүй байдлыг мэдэж, улмаар Бурханы өмнө дуулгаваргүй байдлаа арилгаж болох юм. Бурхан “ангилж ялгахыг” хүсдэг гэдгийг уншаад хүмүүсийн ааш зан даруй түгшиж, булчин нь ч гэсэн хөдлөхөө больсон мэт санагддаг. Тэд өөрсдийгөө шүүмжлэхийн тулд Бурханы өмнө нэн даруй буцан ирж, Бурханыг мэдэж авдаг. Үүний дараа—тэднийг сэтгэл шулуудсаны дараа—Бурхан боломжийг ашиглан агуу улаан лууны мөн чанарыг тэдэнд харуулдаг; тиймээс хүмүүс сүнсний ертөнцтэй шууд харилцдаг ба шийдвэр нь үүрэг гүйцэтгэж эхэлснээс болж оюун ухаан нь ч бас үүрэг гүйцэтгэж эхэлдэг, энэ нь Бурхан хүн хоёрын хоорондох уян сэтгэлийг ихэсгэдэг—энэ нь махбод дахь Бурханы ажилд илүү их ашиг тустай юм. Ийм маягаар хүмүүс өөрийн эрхгүй өнгөрсөн цаг хугацааг дурсах сэтгэлтэй байдаг: Урьд нь хүмүүс олон жилийн турш тодорхойгүй Бурханд итгэсэн; олон жилийн турш тэд зүрх сэтгэлдээ хэзээ ч чөлөөлөгдөж байгаагүй, асар их таашаал авч чадахгүй байсан бөгөөд хэдий Бурханд итгэж байсан ч амьдралд нь ямар ч эмх цэгц байгаагүй. Тэдний амьдрал мөн л хоосон, найдлагагүй санагдаж, итгэгч болохоос өмнөх амьдралаас нь ямар ч ялгаагүй мэт байсан ба тухайн үеийн тэдний итгэл ээдрээтэй санагддаг, үл итгэлээс өөрцгүй байв. Тэд өнөөдрийн бодитой Бурханыг Өөрийг нь харсан тул тэнгэр, газар шинэчлэгдсэн мэт байдаг; тэдний амьдрал гэрэлтэй болж, тэд итгэл найдваргүй байхаа больж, бодитой Бурхан ирсний улмаас зүрх сэтгэлдээ тууштай, сүнсэндээ амар амгалан байдаг. Тэд хийж буй бүхэндээ салхийг хөөж, сүүдрээс зуурахаа больдог; тэдний эрэл хайгуул зорилгогүй байхаа больдог ба тэд гараа савчуулахаа больдог. Өнөөдрийн амьдрал бүр ч илүү сайхан, хүмүүс санамсаргүй хаанчлалд орж, Бурханы ардын нэг болсон ба дараа нь… Зүрх сэтгэлдээ хүмүүс энэ талаар бодох тусам, төдий чинээ сайхан байдаг; энэ талаар бодох тусмаа тэд улам аз жаргалтай болж, Бурханыг хайрлахаар улам зоригждог. Тиймээс нэг л мэдэхэд Бурхан хүн хоёрын хоорондох найрамдал сайжирдаг. Хүмүүс Бурханыг

илүү их хайрлаж, Бурханыг илүү их мэдэж, хүн дэх Бурханы ажил улам амархан болдог бөгөөд энэ нь хүмүүсийг хүчилж, эсвэл албаддаггүй, харин байгалийн жамыг дагаж, хүн өөрийн өвөрмөц чиг үүргийг биелүүлдэг—ийм маягаар л хүмүүс Бурханыг аажмаар мэдэж чадна. Зөвхөн энэ л Бурханы мэргэн ухаан—энэ нь өчүүхэн төдий ч хичээл чармайлт шаарддаггүй, хүний уг чанарт нийцүүлэн хэрэглэгддэг. Тиймээс энэ мөчид Бурхан: “Намайг хүний ертөнцөд бие махбодтой болсон үед хүн төрөлхтөн Миний удирдамж дор өөрийн мэдэлгүй өдий хүрч, өөрийн мэдэлгүй Намайг мэдэж авсан. Гэвч өмнө нь буй замаар яг хэрхэн алхах талаар хэн ч таамагладаггүй, хэн ч мэддэггүй—тэрхүү зам өөрсдийг нь хааш аваачихыг мэдэх хүн бүр ч байдаггүй. Зөвхөн Төгс Хүчит харж хандвал л хүн замын төгсгөл хүртэл явж чадна; зүүн зүг дэх аянгаар замчлуулснаар л хүн Миний хаанчлалын хаалгаар алхан орж чадна” гэж хэлсэн. Хүний зүрх сэтгэлд, дээр дүрсэлсэн зүйлийн минь дүгнэлт яг энэ биш гэж үү? Энд Бурханы үгийн нууц оршдог. Хүний зүрх сэтгэлдээ бодож буй зүйл чухамдаа Бурханы Өөрийнхөө амаар хэлдэг зүйл бөгөөд Бурханы амаараа хэлдэг зүйл нь хүний хүсэн эрмэлздэг зүйл юм. Чухамдаа хүний зүрх сэтгэлийг илчлэхдээ Бурханы хамгийн чадамгай хийдэг зүйл энэ юм; эс бөгөөс бүх хүн яаж чин сэтгэлээсээ үнэмшиж чадах юм бэ? Энэ нь агуу улаан лууг байлдан дагуулснаар Бурханы хүрэхийг хүсдэг үр нөлөө биш гэж үү?

Үнэн хэрэгтээ, Бурханы анхдагч санаа зорилго өнгөц утгыг нь илтгэдэггүй олон үг бий. Өөрийнхөө олон үгээр Бурхан зүгээр л хүмүүсийн үзлийг зориуд өөрчилж, тэдний анхаарлыг өөр зүгт хандуулахаар зорьдог. Бурхан эдгээр үгэнд ямар ч ач холбогдол өгдөггүй тул олон үгийг тайлбарлууштай биш юм. Хүн өнөөдрийн түвшинд хүртлээ Бурханы үгээр байлдан дагуулагдсан байх үед хүмүүсийн хүч чадал тодорхой хэмжээнд хүрдэг тул дараа нь Бурхан илүү их анхааруулсан үгийг буюу Бурханы ардуудад зориулан гаргасан Өөрийн үндсэн хуулийг айлдсан: “Хэдийгээр газар дэлхийд суурьшсан хүмүүс тэнгэрийн од шиг тоо томшгүй олон боловч Би тэднийг бүгдийг нь алган дээрээ тавьсан мэт тодорхой мэддэг. Мөн Намайг ‘хайрладаг’ хүмүүс далайн элс мэт тоолж баршгүй хэдий ч тун цөөхөн хүнийг л Би сонгодог: Намайг ‘хайрладаг’ хүмүүсээс гадна хурц гэрлийг эрэлхийлдэг хүмүүс л сонгогддог.” Үнэндээ Бурханыг хайрладаг гэж хэлдэг хүн олон байдаг боловч зүрх сэтгэлээсээ Түүнийг хайрладаг хүн цөөхөн байдаг. Нүдээ аньсан ч гэсэн үүнийг тодорхой танин мэдэж болох юм шиг байдаг. Бурханд итгэдэг хүмүүсийн бүхий л ертөнц үнэндээ ийм байдаг. Үүнээс бид, одоо Бурхан “хүмүүсийг ангилж ялгах” ажилд орсон гэдгийг хардаг ба Бурханы хүсдэг зүйл, Бурханыг хангалуун болгодог зүйл нь өнөөдрийн чуулган биш, харин ангилж ялгасны дараах хаанчлал юм гэдгийг энэ нь харуулдаг. Энэ мөчид Тэрээр бүх “аюултай бараанд” цаашдын анхааруулга өгдөг: Бурхан үйлдэл хийхгүй л биш бол, Бурханыг үйлдэж эхэлмэгц энэ хүмүүс хаанчлалаас арчигдан хаягдана. Бурхан юмыг хэзээ ч хааш яаш хийдэггүй. Тэр үргэлж “нэг бол нэг, хоёр бол хоёр” хэмээх зарчмын дагуу үйлддэг бөгөөд хэрвээ Түүний харахыг хүсдэггүй хүмүүс байгаа бол хожим төвөг

учруулахыг нь болиулахын тулд тэднийг арчин хаяхаар боломжтой бүхнийг хийдэг. Үүнийг “хог хаягдлыг арилгаж, нэгд нэггүй цэвэрлэх” гэж нэрлэдэг. Бурхан хүнд захиргааны зарлигийг зарлах яг тэр үе нь Тэр Өөрийн гайхалтай үйл хэргийг болон Өөрийн дотор буй бүх зүйлийг харуулах үе бөгөөд тиймээс дараа нь Тэр: “Ууланд тоймгүй олон зэрлэг араатан байдаг ч Миний өмнө бүгд хонь шиг номхон байдаг; далайн давлагаан дор ойлгошгүй олон гайхамшиг оршдог боловч Миний өмнө өөрсдийгөө газрын гадарга дээрх бүх зүйлтэй адил тодорхой харуулдаг; дээд тэнгэрүүдэд хүний хэзээ ч хүрч чадахгүй ертөнц байдаг, харин тэдгээр хүршгүй ертөнцөд Би чөлөөтэй алхалдаг” гэсэн. Бурханы утга санаа энэ: Хэдийгээр хүний зүрх сэтгэл бүх зүйлээс илүү хуурамч, хүмүүсийн үзлийн там шиг эцэс төгсгөлгүй нууцлаг санагддаг ч Бурхан хүний бодит байдлыг нэвт шувт мэддэг. Бүх зүйлийн дундаас хүн бол зэрлэг араатнаас илүү харгис, хэрцгий амьтан атал хэн ч босон, эсэргүүцэж зүрхлэхгүй байх хэмжээнд Бурхан хүнийг байлдан дагуулсан. Үнэндээ Бурханы санаа зорилгын дагуу бол, хүмүүсийн зүрх сэтгэлдээ боддог зүйл бүх зүйлийн дундах бүх зүйлээс ч илүү ээдрээтэй, ойлгогдошгүй боловч Бурхан хүний зүрх сэтгэлийг огт тоодоггүй. Тэр үүнийг зүгээр л нүднийх нь өмнөх өчүүхэн өт мэт үздэг. Өөрийн амнаас гарсан үгээр Тэр үүнийг байлдан дагуулдаг; хүссэн үедээ Тэр үүнийг цохин унагадаг; гарынхаа өчүүхэн хөдөлгөөнөөр л үүнийг гэсгээдэг; Тэр үүнийг хүссэнээрээ ялладаг.

Өнөөдөр бүх хүн харанхуйн дунд оршдог боловч Бурханы ирэлтээс болж, Бурханыг харсны үр дүнд хүмүүс гэрлийн мөн чанарыг эцэст нь мэдэж авдаг. Дэлхий ертөнц даяар, газар дээр том хар тогоо хөмөрсөн юм шиг байдаг ба хэн ч амьсгаа авч чаддаггүй; тэд бүгдээрээ нөхцөл байдлыг өөрчлөхийг хүсдэг мөртөө тогоог хэн ч, хэзээ ч өргөөгүй. Бие махбодтой болсон Бурханы улмаас л хүмүүсийн нүд гэнэтхэн нээгдэж, бодитой Бурханыг харсан. Тиймээс Бурхан тэднээс байцаасан өнгөөр ингэж асуудаг: “Хүн Намайг гэрэлд хэзээ ч таниагүй, харин Намайг харанхуйн ертөнцөд л харсан. Та нар ч гэсэн өнөөдөр яг адилхан нөхцөл байдалд байгаа биш гэж үү? Агуу улаан лууны галзуу хилэн оргилдоо хүрэх цагт Би Өөрийн ажлыг албан ёсоор махбодоор эхлүүлсэн.” Бурхан сүнсний ертөнцийн бодит нөхцөл байдлыг нуудаггүй, мөн хүний зүрх сэтгэлийн бодит байдлыг ч нуудаггүй, тиймээс Тэр хүмүүст удаа дараа сануулдаг: “Би Өөрийн ардуудад бие махбодтой болсон Бурханыг мэдүүлээд зогсохгүй, бас тэднийг цэвэрлэдэг. Миний захиргааны зарлиг хатуу чандаас болж хүмүүсийн дийлэнх олонх нь Надад таягдуулан хаягдах аюулд байсаар байгаа. Та нар өөрсөдтэйгөө харьцахын тулд хамаг хичээл чармайлтаа гаргаж, өөрсдийн биеийг захирахгүй бол—ингэхгүй л бол яг л Паул Миний гараас гэсгээлт хүртээд, үүнээс зугтах аргагүй байсантай адилаар Миний жигшин голдог бай болж, там руу хаягдах нь гарцаагүй.” Бурханыг ийм зүйл хэлэх тусам, тэр үед л хүмүүс өөрсдийнхөө алхамд улам хянамгай болж, Бурханы захиргааны зарлигаас улам их айдаг; тэр үед л Бурханы эрх мэдэл хэрэгжиж, Түүний сүр жавхлан ил болж чадна. Хүмүүст Бурханы хүслийг ойлгуулахын тулд

энд Паулыг дахин нэгэнтээ дурдсан: Тэд Бурханаар гэсгээгддэг хүмүүс байх ёсгүй, харин Бурханы хүслийг хайхардаг хүмүүс байх ёстой. Зөвхөн энэ нь л, Бурханыг бүрэн сэтгэл хангалуун байлгахын тулд Бурханы өмнө гаргасан урьдын шийдвэрээ биелүүлж чадаагүйгээ айдсынхаа дунд эргэн санахад хүмүүсийг хүргэж чадах бөгөөд энэ нь тэднийг бүр ч их харамсуулж, бодитой Бурханы талаар илүү их мэдлэгтэй болгодог. Тиймээс тэр үед л тэд Бурханы үгийн талаар ямар ч эргэлзээгүй байж чадна.

“Хүн ердөө махбодод байгаа Намайг мэддэггүй ч юм биш; үүнээс гадна тэр махан биед оршдог өөрийгөө ч ойлгож чадаагүй. Маш олон жилийн турш хүмүүс Намайг мэхэлж, Надад гаднаас ирсэн зочин мэт хандсаар ирсэн. Маш олон удаа…” Энэ “маш олон удаа” гэх жагсаалт Бурханыг эсэргүүцэх хүний эсэргүүцлийн бодит байдлыг жагсаан, хүмүүст гэсгээлтийн бодит жишээг харуулсан; энэ нь нүглийн нотолгоо бөгөөд хэн ч үүнийг дахин няцааж чадахгүй. Бүх хүн Бурханыг өдөр тутмын хэрэгцээт зүйл мэт ашигладаг ба Тэрээр өөрсдийнх нь хүссэнээрээ ашиглаж болох ахуйн хэрэглээний бараа мэт байдаг. Хэн ч Бурханыг нандигнан хайрладаггүй; Бурханы гоо сайхныг, Бурханы алдар суут дүр төрхийг мэдэхээр хэн ч хичээгээгүй, Бурханд захирагдах санаа зорилго хэнд ч байдаггүй. Мөн Бурханыг өөрсдийнх нь зүрх сэтгэл дэх хайртай зүйл гэж хэн ч, хэзээ ч үзээгүй; өөрсдөд нь хэрэгтэй үед бүгд Түүнийг зулгаадаг ба хэрэггүй байх үед Түүнийг нэг тийш хаяад, үл ойшоодог. Хүний хувьд Бурхан дураараа удирдаж болох, мөн хүссэнээрээ, дур зоргоороо шаардлага тавьж болох хүүхэлдэй мэт байдаг. Гэхдээ Бурхан: “Хэрвээ бие махбодтой байх хугацаандаа Би хүний сул талыг өрөвдөөгүй бол гагцхүү бие махбодтой болсноос минь болж бүх хүн ухаанаа алдтал айчхаад, түүнийхээ уршгаар Үхэгсдийн оронд уначихсан байх байлаа” гэж хэлсэн ба Бурхан бие махбодтой болохын ач холбогдол хэчнээн агуу болохыг энэ нь харуулдаг: Тэрээр сүнсний ертөнцөөс бүх хүн төрөлхтнийг устгахын оронд хүн төрөлхтнийг махбодоор байлдан дагуулахын тулд ирсэн. Тиймээс Үг махбод болоход хэн ч мэдээгүй. Хэрвээ Бурхан хүний сул дорой байдлыг анхаардаггүй байсан бол, мөн Түүнийг махбод болох үед тэнгэр, газар орвонгоороо эргэсэн бол бүх хүн устах байв. Шинэд дурлаж, хуучныг үзэн ядах нь хүний уг чанарт байдаг бөгөөд тэд аливаа зүйл төвөггүй байх үед муу цагийг үргэлж мартан, хэчнээн их ерөөгдсөнөө хэн ч мэддэггүй тул өдий хүрэх нь хэчнээн хэцүү бэрх байсныг эрхэмлэх ёстой гэж Бурхан тэдэнд удаа дараа сануулсан; маргаашийн төлөө тэд өнөөдрийг бүр ч их эрхэмлэх ёстой бөгөөд эзнээ танилгүй өндөрт авиран гардаг амьтантай адилаар дунд нь амьдарч буй ерөөлийг мэдэхгүй байх ёсгүй. Тиймээс хүмүүс ааш авир сайтай болж, цаашид бардам, биеэ тоосон зантай байхаа болиод, хүний уг чанар сайн байдаг юм биш, харин Бурханы өршөөл, хайр хүн дээр иржээ гэдгийг мэдэж авдаг; тэд бүгдээрээ гэсгээлтээс айдаг болохоор өөр юу ч хийж зүрхэлдэггүй.

13-Р БҮЛЭГ

Бурхан агуу улаан лууны бүх үр удмыг үзэн яддаг ба агуу улаан лууг өөрийг нь бүр ч их үзэн яддаг: Энэ нь Бурханы зүрх сэтгэл доторх уур хилэнгийн эх сурвалж юм. Бурхан агуу улаан лууд харьяалагддаг бүх зүйлийг үнсэн товрог болгохын тулд гал болон хүхэрт нуур луу шидэхийг хүсдэг юм шиг санагддаг. Бурхан агуу улаан лууг газрын хөрснөөс биечлэн арчин хаяхын тулд Өөрийн гарыг сунгахыг хүсдэг юм шиг санагдах үе ч бий—зөвхөн тэр нь л Түүний зүрх сэтгэл дэх үзэн ядалтыг арилгаж чадах юм. Агуу улаан лууны гэр дэх хүн нэг бүр бол хүн чанаргүй араатан юм, ийм учраас Бурхан уураа хүчлэн дарж, ингэж хэлсэн юм: “Миний бүх ард, Миний бүх хөвгүүдийн дундаас, өөрөөр хэлбэл, бүх хүн төрөлхтнөөс Миний сонгож авсан хүмүүсийн дундаас та нар хамгийн доод бүлэгт харьяалагддаг” Бурхан агуу улаан луутай өөрийнх нь нутагт шийдвэрлэх тулаан хийж эхэлсэн бөгөөд төлөвлөгөө нь үр дүнд хүрэх үед Тэрээр үүнийг устгаад, хүн төрөлхтнийг завхруулах юм уу сүнсийг нь сүйтгэх боломж олгохоо болино. Бурхан унтаж буй ардуудаа аврахын тулд өдөр бүр дууддаг ч тэд бүгдээрээ нойрны эм уусан юм шиг манарсан байдалтай байдаг. Хэрвээ Бурхан тэднийг сэрээхээ хормын төдийд ч гэсэн болих юм бол тэд унтаа байдалдаа буцан ороод, юу ч анзаарахгүй байх болно. Түүний бүх ардын биеийнх нь гуравны хоёр мэдээгүй болсон мэт санагддаг. Тэд өөрсдийнхөө хэрэгцээг, эсвэл дутагдлыг мэддэггүй, бүр юу өмсөж, юу идэх ёстойгоо ч мэддэггүй. Агуу улаан луу хүмүүсийг завхруулахын тулд асар их хичээл чармайлт гаргасныг харуулахад энэ нь хангалттай юм. Үүний муу муухай байдал Хятадын бүх бүс нутаг даяар түгдэг ба энэ нь хүмүүсийг зэвүүцүүлдэг болохоор тэд энэхүү доройтсон, бүдүүлэг улс оронд цаашид байх хүсэлгүй болдог. Бурханы хамгийн их үзэн яддаг зүйл нь агуу улаан лууны мөн чанар юм, ийм учраас Тэр уурласандаа хүмүүст өдөр болгон сануулга өгч, хүмүүс Түүний хилэнт нүдний дор өдөр бүр амьдардаг. Тэгсэн ч гэсэн, ихэнх хүмүүс Бурханыг эрж хайхаа мөн л мэддэггүй; харин зүгээр л ажиглан сууж, хооллуулахаар хүлээж байдаг. Тэд өлбөрч үхэх гэж байсан ч гэсэн өөрсдөө хоол олохыг мөн л хүсэхгүй. Хүний мөс чанарыг Сатан аль хэдийн завхруулсан бөгөөд мөн чанартаа цэвдэг сэтгэлтэй болж өөрчлөгдсөн. Бурхан: “Хэрвээ Би сануулаагүй бол та нар одоо ч гэсэн сэрээгүй, харин хөлдсөн мэт, мөн ичээндээ орсон мэт хэвээр үлдэх байлаа” гэж хэлсэнд гайхах юмгүй. Хүмүүс ичээлсэн амьтад шиг, хоол ундны шаардлагагүйгээр өвлийг өнгөрөөж буй мэт байдаг; энэ нь чухамдаа Бурханы ардуудын одоогийн нөхцөл байдал юм. Яг ийм учраас Бурхан хүмүүсээс бие махбодтой болсон Бурханыг Өөрийг нь гэрэлд мэдэж авахыг л шаарддаг; асар их өөрчлөгд, эсвэл өөрсдийнхөө амийг асар их өсгө гэж Тэр хүмүүсээс шаарддаггүй. Тэр нь бохир, бузар агуу улаан лууг ялж, улмаар Бурханы агуу хүч чадлыг бүр ч их харуулахад хангалттай байх болно.

Хүмүүс Бурханы үгийг унших үедээ үгчилсэн утгыг нь л ойлгодог бөгөөд сүнслэг ач холбогдлыг нь ойлгох чадваргүй байдаг. Ердөө л “булингартсан давлагаа”

хэмээх үг баатар, аваргуудыг бүгдийг нь мухардуулсан. Бурханы уур хилэн харагдах үед Түүний үг, үйлдэл болон зан чанар булингартсан давлагаа мэт байдаг бус уу? Бурхан бүх хүн төрөлхтнийг шүүх үе нь Түүний уур хилэнг илчилдэггүй гэж үү? Энэ нь, тэрхүү булингартсан давлагаа үр нөлөөгөө үзүүлэх үе биш гэж үү? Өөрсдийнхөө завхралаас болоод тийм булингартсан давлагааны дунд амьдардаггүй хэн байна вэ? Өөрөөр хэлбэл, Бурханы уур хилэнгийн дунд амьдардаггүй хэн байна вэ? Бурхан хүн төрөлхтөнд гай гамшиг оноохыг хүсдэг үе нь хүмүүс “нүргэлэх үй олон хар үүлсийг” хардаг үе биш гэж үү? Гай гамшгаас зугтдаггүй ямар хүн байх билээ? Бурханы уур хилэн аадар бороо мэт асгарч, хүмүүс рүү хүчит салхи мэт үлээдэг. Хүмүүс бүгд хуйларсан цасан шуургатай тулгарсан мэт Бурханы үгээр ариусгагддаг. Хүн төрөлхтний хувьд Бурханы үг ухан ойлгоход хамгийн хэцүү байдаг. Өөрийнхөө үгээр Тэр дэлхий ертөнцийг бүтээсэн бөгөөд Өөрийнхөө үгээр бүх хүн төрөлхтнийг удирдаж, ариусгадаг. Эцэст нь Бурхан Өөрийнхөө үгээр дамжуулан бүхий л орчлон ертөнцийн цэвэр ариун байдлыг сэргээнэ. Бурханы Сүнсний оршин тогтнол хий хоосон биш гэдгийг Түүний хэлдэг юм бүхнээс харж болно, зөвхөн Түүний үгээс л хүмүүс хэрхэн амьд үлдэхээ зэрвэсхэн харж чадна. Түүний үг амийн хангалтыг агуулдаг учраас хүмүүс бүгд тэдгээрийг нандигнадаг. Хүмүүс Бурханы үгэнд анхаарлаа төвлөрүүлэх тусам, Бурхан тэдэнд илүү их асуулт тавьдаг—тэр асуултууд нь тэднийг будилуулж, хариулах боломжгүй болгож орхидог. Бурханы дараалсан асуултууд нь дангаараа, хэсэг хугацаанд хүмүүсээр тунгаан бодуулахад хангалттай бөгөөд Түүний үгийн үлдсэн хэсгийг хэлэхийн ч хэрэггүй. Бурханд бүх зүйл үнэхээр бүрэн дүүрэн, элбэг дэлбэг байдаг, юу ч дутагддаггүй. Гэвч, хүмүүс үүний ихээхнийг эдэлж чаддаггүй; тэд тахианы арьсыг харж байгаа ч махыг нь идэж чаддаггүй хүн мэт Түүний үгийн өнгөц талыг л мэддэг. Хүмүүсийн зол завшаан хомсхон болохоор Бурханыг таашааж чаддаггүй гэдгийг энэ нь харуулдаг. Хүн бүрийн үзэлд өөрсдийнх нь Бурханы дүр байдаг, ийм учраас тодорхойгүй Бурхан гэж юу болохыг, эсвэл Сатаны дүр төрх ямар болохыг хэн ч мэддэггүй. Тиймээс Бурханыг “Учир нь чиний итгэдэг зүйл ердөө Сатаны дүр бөгөөд Бурхантай Өөртэй нь ямар ч хамаагүй” хэмээн хэлэх үед бүгд балмагдан цочирдсон: Тэд маш олон жилийн турш итгэсэн мөртөө өөрсдийнх нь итгэж байсан зүйл Бурхан Өөрөө биш, харин Сатан байсан гэдгийг мэдээгүй байсан. Тэд дотроо гэнэтийн хоосролыг мэдэрсэн боловч юу хэлэхээ мэдээгүй юм. Тэгээд тэд дахин будилж эхэлсэн. Ийм маягаар ажилласнаар л хүмүүс шинэ гэрлийг илүү сайн хүлээн авч, улмаар хуучны зүйлсийг үгүйсгэж чадна. Хэчнээн сайн санагдах нь хамаагүй тэдгээр зүйл нэмэргүй. Бодитой Бурханыг Өөрийг нь ойлгох нь хүмүүст илүү ач тустай; энэ нь зүрх сэтгэлийг нь эзэлж буй өөрсдийнхөө үзлийн байр сууриас ангижирч, Бурханд Өөрт нь зүрх сэтгэлээ эзэмдүүлэх боломжийг тэдэнд олгодог. Ийм маягаар л бие махбодтой болсны ач холбогдол биелж, өөрсдийнхөө нүдээр бодитой Бурханыг Өөрийг нь танин мэдэхэд хүмүүсийг хүргэдэг.

Бурхан хүмүүст сүнсний ертөнцийн нөхцөл байдлын талаар олон удаа хэлсэн: “Сатаныг Миний өмнө ирэхэд Би түүний зэрлэг догшин байдлаас айж ухардаггүй, бас үзэшгүй муухай байдлаас нь ч сүрддэггүй: Би зүгээр л үл ойшоодог.” Хүмүүс үүнээс бодит байдал дээрх нөхцөл байдлыг л ойлгосон; тэд сүнсний ертөнцийн үнэнийг мэддэггүй. Бурхан махбод болсон учраас Сатан элдэв янзын буруутгал ашиглан, Бурхан руу тийнхүү маягаар дайрч довтлохоор найдсан юм. Гэвч Бурхан ухарч няцдаггүй; Тэр зүгээр л хүн төрөлхтний дунд үг хэлж, ажиллан, махбод болсон биеэрээ дамжуулан Өөрийгөө хүмүүст мэдүүлдэг. Сатан үүнд уурсан нүд нь улаанаар эргэлддэг бөгөөд Бурханы ардуудыг сөрөг болгож, ухарч няцахад хүргэж, бүр замыг нь алдуулахын тулд асар их хичээл чармайлт гаргасан. Гэхдээ Бурханы үгийн үр нөлөөнөөс болж Сатан бүрмөсөн бүгэлгүйтээд, харгис догшин авир нь нэмэгдсэн. Тиймээс Бурхан хүн бүрд ийнхүү сануулсан юм: “Амьдралдаа ийм нөхцөл байдалтай нүүр тулах өдөр чамд ирж болох юм: Чи дуртайяа Сатанд олзлуулахыг хүсэж байна уу, эсвэл Надаар авхуулах уу?” Хэдийгээр хүмүүс сүнсний ертөнцөд тохиолддог зүйлсийн талаар мэддэггүй ч Бурханы ийм үгийг сонсмогцоо хаширлаж, айдаг. Энэ нь Сатаны дайралтад хариу цохилт өгч, Бурханы алдрыг хангалттай харуулдаг. Ажлын шинэ арга барилд аль хэдийн орсон хэр нь хүмүүс хаанчлал дахь амьдралын талаар тодорхой мэдэхгүй хэвээр байдаг бөгөөд ойлголоо ч гэсэн тодорхой байдал дутагддаг. Тиймээс хүмүүст анхааруулга өгснийхөө дараа Бурхан тэдэнд хаанчлал дахь амьдралын мөн чанарыг танилцуулсан: “Хаанчлалын амьдрал бол хүмүүсийн болон Бурханы Өөрийн амьдрал юм.” Бурхан Өөрөө бие махбодтой болсон болохоор гурав дахь тэнгэрийн амьдрал газар дээр биеллээ олсон. Энэ нь Бурханы төлөвлөгөө төдий биш—Тэрээр үүнийг биелүүлсэн. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүмүүс Бурханыг Өөрийг нь улам сайн мэдэж авч, улмаар Бурхан бол тэнгэр дэх тодорхойгүй Бурхан биш, харин газар дээр байгаа гэдгийг үнэхээр мэдэрсэн учраас тэнгэрийн амьдралыг улам их амталж чаддаг. Тиймээс газар дээрх амьдрал нь тэнгэр дэх амьдралтай адилхан. Бодит байдал дээр бие махбодтой болсон Бурхан хүний ертөнцийн гашуун амтыг амсдаг бөгөөд хэдий чинээ тэгж чадна, Тэр бол бодитой Бурхан Өөрөө гэдгийг энэ нь төдий чинээ их нотолдог. Тиймээс “Миний оршин суудаг газар бол Миний нуугддаг газар юм—ямартай ч Өөрийн оршин суудаг энэхүү газарт Би бүх дайснаа ялсан; Өөрийн оршин суудаг газартаа Би газар дээр амьдрах бодитой туршлагыг олж авсан; Өөрийн оршин суудаг газартаа Би хүний үг үйлдэл бүрийг ажиглаж, бүхий л хүн төрөлхтнийг харж хандаж, захирч байна” гэх үг нь өнөөдрийн Бурхан бодитой гэх баримтыг хангалттай нотолдог. Махбодод үнэхээр амьдарч, хүмүүний амьдралыг махбодоор үнэхээр туулж, бүх хүн төрөлхтнийг махбод дотроос үнэхээр ойлгож, хүн төрөлхтнийг махбодоор үнэхээр байлдан дагуулж, агуу улаан луутай хийх шийдвэрлэх тулааныг махбодоор үнэхээр хийж, Бурханы бүх ажлыг махбодоор хийх—энэ нь чухамдаа бодитой Бурханы Өөрийн оршин тогтнол биш гэж үү? Гэсэн ч хүмүүс Бурханы хэлсэн энэ ердийн нэг мөрүүд дэх

цаад санааг харах нь тун ховорхон байдаг; тэд ердөө зэрвэс гүйлгэн хардаг бөгөөд Бурханы үгийн эрхэм нандин, ховор байдлыг мэдэрдэггүй.

Бурханы үг тун сайн шилждэг. “Хүн төрөлхтөн комд орсон байгаа тул” хэмээх хэллэг нь Бурханы Өөрийн дүрслэлийг авч, бүх хүн төрөлхтний байр байдлын дүрслэл болгон хувиргадаг. Энд буй “хүйтэн цацрагийн гэрэл” гэдэг нь зүүн зүгийн аянгыг төлөөлдөггүй; харин энэ нь Бурханы үг буюу Түүний ажиллах шинэ арга барил гэсэн үг юм. Тиймээс хүмүүсийн төрөл бүрийн хөдөлгөөнийг үүнээс харж болно: Шинэ арга барилд орсныхоо дараа бүх хүн зүг чигийн мэдрэмжээ алдаад, хаанаас ирснээ ч, хаашаа явж байгаагаа ч мэддэггүй. “Ихэнх хүмүүс лазерынх мэт туяанд цохиулан” гэдэг нь шинэ арга барилаар таягдан хаягддаг хүмүүсийг хэлдэг; тэд шалгалтуудыг давж, эсвэл зовлонгийн цэвэршүүлэлтийг туулж чаддаггүй, тиймээс ёроолгүй нүх рүү дахин нэгэнтээ шидэгддэг. Бурханы үг хүн төрөлхтнийг тодорхой түвшинд ил болгодог болохоор хүмүүс Бурханы үгийг харах үедээ айдаг юм шиг санагддаг бөгөөд зүрх рүү нь пулемётын ам чиглэхийг харсан мэт юу ч хэлж зүрхэлдэггүй. Гэхдээ тэд Бурханы үгэнд сайн зүйлс байдаг гэдгийг ч бас мэдэрдэг. Тэдний зүрх сэтгэлд асар их зөрчилдөөн байдаг бөгөөд тэд юу хийх ёстойгоо мэддэггүй. Гэхдээ итгэлээсээ үүдэн тэд зүгээр л өөрсдийгөө хатамжилж, Бурхан өөрсдийг нь орхих вий гэж айсандаа Түүний үгийг илүү гүнзгий судалдаг. Бурханы хэлсэнчлэн: “Хүмүүсийн дунд ийм байдалд эс орших хэн байна вэ? Миний гэрэлд эс орших хэн байна вэ? Чи хүчтэй байлаа ч, эсвэл сул дорой байлаа ч айсуй гэрлээс минь зайлсхийж яахан чадах билээ?” Хэрвээ Бурхан хэн нэгнийг ашиглах юм бол сул дорой байсан ч гэсэн Өөрийнхөө гэсгээлтээр гэгээрүүлж, гэрэлтүүлнэ; иймээс хүмүүс Бурханыг үгийг унших тусмаа, Түүнийг улам их ойлгож, улам хүндлэх ба болчимгүй байж төдий чинээ зүрхлэхгүй. Хүмүүс өнөөдрийн байгаа түвшиндээ хүрсэн нь бүхэлдээ Бурханы агуу хүч чадлаас болж байгаа юм. Түүний үгийн эрх мэдлээс болж, өөрөөр хэлбэл, Түүний үгэн дэх Сүнсний улмаас хүмүүс Бурханаас эмээдэг. Бурхан хүн төрөлхтний жинхэнэ царайг илчлэх тусам, Түүнийг гэх бишрэл нь нэмэгдэж, улмаар Түүний оршин тогтнолын бодит байдлын талаар төдий чинээ их итгэлтэй болдог. Энэ нь хүн төрөлхтний Бурханыг ойлгох зам дээрх гэрэлт цамхаг, мөн тэдэнд Бурханы өгсөн ул мөр юм. Энэ талаар анхааралтай бодоод үз: Тийм байгаа биз дээ?

Дээр дурдсан зүйл хүн төрөлхтний урдах замыг гэрэлтүүлдэг гэрэлт цамхаг биш гэж үү?

14-Р БҮЛЭГ

Хүмүүс Бурханы үгээс хэзээ ч, юу ч ухаараагүй. Харин ч тэд жингхэнэ утга учрыг нь ойлголгүйгэр, тэдгээрийг ердөө өнгөцхөн “нандигнадаг”. Тиймээс, хэдийгээр ихэнх хүн Бурханы айлдваруудад дуртай байдаг ч үнэндээ тэдгээрийг хайрладаггүй

гэж Бурхан хэлдэг. Үүний учир нь, Бурханы үзэл бодлоор бол Түүний үг хэдийгээр эрдэнэс мөн боловч хүмүүс жинхэнэ сайхан амтыг нь амтлаагүй. Тийм болохоор тэд зөвхөн “чавганы тухай бодлоороо цангаагаа тайлж”, улмаар шунахай зүрх сэтгэлээ дарж л чаддаг. Бүх хүний дунд Бурханы Сүнс ажиллаж байгаагаар үл барам, мэдээж бас Бурханы үгийн гэгээрэл өгөгддөг; хүмүүс зүгээр л үүний мөн чанарыг үнэхээр ойлгож ухаарахдаа хэтэрхий хэнэггүй. Хүмүүсийн оюун ухаанд, одоо үе бол хаанчлал бүрэн биеллээ олж буй эрин үе боловч мөн чанартаа тийм биш. Бурханы зөгнөдөг зүйл нь Түүний гүйцэлдүүлсэн зүйл байдаг хэдий ч бодит хаанчлал газар дээр хараахан бүрэн ирээгүй байгаа. Харин хүмүүс өөрчлөгдөхийн хэрээр, ажил ахиж дэвшихийн хэрээр, мөн Зүүн зүгээс аянга гарч ирэхийн хэрээр, өөрөөр хэлбэл, Бурханы үг гүнзгийрэхийн хэрээр хаанчлал газар дээр аажмаар бий болж, энэ дэлхий дээр алгуурхан атлаа бүрэн дүүрэн бууж ирнэ. Хаанчлалын ирэлтийн үйл явц ч бас газар дээрх бурханлаг ажлын үйл явц юм. Энэ зуур Бурхан газар дэлхийг тэр чигт нь өөрчлөн байгуулахын тулд түүхийн бүх эрин үеийн туршид хийгдэж байгаагүй ажлыг орчлон ертөнц даяар эхлүүлсэн билээ. Жишээлбэл, Израиль Улс дахь өөрчлөлт, Америкийн Нэгдсэн Улс дахь төрийн эргэлт, Египет дэх өөрчлөлт, Зөвлөлт Холбоот Улсад гарсан өөрчлөлт, Хятадын уналт зэргийг оролцуулаад орчлон ертөнц даяар үлэмж их өөрчлөлт гарч байна. Бүхий л орчлон ертөнц төвхнөж, хэвийн байдалдаа сэргэмэгц Бурханы газар дээрх ажил дуусна; тэр үед хаанчлал газар дээр ирнэ. Энэ нь “Дэлхийн бүх улс гүрэн хагаран бутрах яг тэр үед Миний хаанчлал бүрэлдэн тогтоно, бас тэр үед Би хувирч, бүхий л орчлон ертөнцтэй нүүр тулна” хэмээх үгийн жинхэнэ утга учир юм. Бурхан хүнээс юу ч нуудаггүй; Тэрээр Өөрийн бүх баялаг байдлын талаар хүмүүст тасралтгүй хэлсэн ч тэд юу гэснийг нь ойлгож чаддаггүй ба Түүний үгийг зүгээр л тэнэг хүн шиг хүлээн зөвшөөрдөг. Ажлын энэ үе шатанд хүмүүс Бурханы хэмжээлшгүй байдлын талаар мэдэж авсан, түүнчлэн Түүнийг ойлгоход хэчнээн хэцүү болохыг одоо ухамсарлаж чаддаг; ийм учраас энэ өдрүүдэд Бурханд итгэх нь гахайд дуу дуулахыг заахтай адил, хамгийн хэцүү зүйл гэж тэдэнд санагдсан. Тэд урхинд орсон хулгана адил туйлын арчаагүй байдаг. Үнэндээ хүн хэр их хүч чадалтай, хэчнээн чадварлаг ур дүйтэй байх нь хамаагүй, эсвэл хязгааргүй их чадавхтай байх нь хамаагүй, Бурханы үгийн тухайд гэвэл ийм зүйлс ямар ч утгагүй. Бурханы нүдэнд хүн төрөлхтөн шатаасан цаасны бөөн үнс нурам төдий, хэрэглэгдэх нь бүү хэл, ямар ч үнэ цэнгүй байдаг. Энэ бол “тэдний үзэл бодлоор бол Би улам нууцлаг, улам бүр ойлгогдошгүй болсон” хэмээх үгийн жинхэнэ утгын төгс тайлбар юм. Бурханы ажил байгалийн хөгжил хөдөлгөөнийг дагаж, хүмүүсийн мэдрэхүйн эрхтнүүдийн хүлээн авч чадах зүйлийн дагуу хийгддэг гэдгийг үүнээс харж болно. Хүний уг чанар бат бэх, гуйвшгүй байх үед Бурханы айлддаг үг тэдний үзэлд бүрэн нийцдэг бөгөөд эдгээр үзэл Бурханыхтай бараг адилхан, өчүүхэн ч ялгаагүй юм шиг санагддаг. Энэ нь хүмүүст “Бурханы бодит байдлыг” бага зэрэг мэдүүлдэг боловч Бурханы үндсэн зорилго энэ биш юм. Бурхан газар дээрх

жинхэнэ ажлаа албан ёсоор эхлэхээсээ өмнө хүмүүст суурьших боломж олгож байгаа. Тиймээс хүмүүсийн хувьд тун будилмаар байдаг энэхүү эхлэлийн явцад, өөрсдийнх нь урьдын санаа бодол буруу байсныг, мөн Бурхан, хүн хоёр тэнгэр, газар мэт өөр бөгөөд огтхон ч адилгүй гэдгийг тэд ухаарч байна. Бурханы үгийг хүний үзлийн үндсэн дээр үнэлж болохоо больсон учраас хүмүүс Бурханыг нэн даруй өөрөөр харж эхэлдэг; үүний үр дүнд тэд, бодитой Бурхан нь ойртохын аргагүй, харагдашгүй, хүршгүй мэт, мөн Бурханы махбод болсон бие Түүний мөн чанаргүй, гадаад тал төдий байдаг мэт Бурханыг гайхширан ширтдэг. Тэрээр бие махбодтой болсон Сүнс хэдий ч хэдийд ч Сүнсний хэлбэрт хувирч, хөвөн одож чадах юм санагддаг тул хүмүүс бага зэрэг сэрэмжилсэн сэтгэхүйтэй болсон. Бурханыг дурдмагц хүмүүс Түүнийг өөрсдийнхөө үзлээр хувцаслан, Тэрээр үүл, манан хөлөглөж, усан дээр алхаж, хүмүүсийн дунд гэнэт гарч ирж, алга болж чадна хэмээн хэлдэг. Зарим хүнд бүр ч тодорхой тайлбар байдаг. Хүмүүсийн мэдлэггүй байдал болон мэдлэг ухаан дутмагаас болж Бурхан: “Намайг эсэргүүцсэн юм уу Миний захиргааны зарлигийг зөрчсөн хэмээн тэднийг бодох үед Би мөн л хараагүй дүр үзүүлдэг” гэсэн юм.

Бурхан хүний муу муухай төрх болон дотоод ертөнцийг хэзээ ч, өчүүхэн төдий ч алдалгүйгээр, туйлын үнэн зөв илчилдэг. Тэр хэзээ ч, ямар ч алдаа гаргадаггүй гэж хэлж ч болно. Энэ нь хүмүүсийг бүрэн үнэмшүүлдэг нотолгоо юм. Бурханы ажлын цаад зарчмаас үүдэн Түүний олон үг, үйл хэрэг арилгах аргагүй сэтгэгдэл үлдээдэг болохоор хүмүүс илүү эрхэм нандин зүйлсийг Түүнээс нээн илрүүлсэн мэт, Түүний талаар бүр ч гүн гүнзгий ойлголттой болдог юм шиг санагддаг. “Тэдний ой санамжид Би бол хүмүүсийг гэсгээхийн оронд өршөөдөг Бурхан, эсвэл хэлсэндээ хүрдэггүй Бурхан Өөрөө юм. Эдгээр нь бүгд хүний бодлоос гарсан төсөөлөл бөгөөд бодит баримттай нийцдэггүй.” Хэдийгээр хүн төрөлхтөн Бурханы жинхэнэ царай төрхөд хэзээ ч ач холбогдол өгч байгаагүй боловч “Түүний зан чанарын хажуу талыг” арван хуруу шигээ мэддэг; тэд Бурханы үг болон үйлдлээс үргэлж өө хайж байна. Учир нь хүмүүс сөрөг зүйлсэд анхаарал хандуулж, эерэг зүйлсийг үл тооход үргэлж бэлэн байж, Бурханы үйл хэргийг гагцхүү дорд үздэг. Бурхан, амьдран суудаг газартаа Өөрийгөө даруухнаар нуудаг гэж хэлэх тусам, хүн төрөлхтөн Түүнээс төдий чинээ ихийг шаарддаг. “Хэрвээ бие махбодтой болсон Бурхан хүн төрөлхтний үйл хэрэг бүрийг ажиглаж, хүний амьдралыг туулж байгаа юм бол ихэнх тохиолдолд яагаад бидний бодит нөхцөл байдлыг мэддэггүй юм бэ? Бурхан үнэхээр нуугдсан гэсэн үг үү?” гэж тэд хэлдэг. Хэдийгээр Бурхан хүний зүрх сэтгэлийн гүнийг хардаг боловч хүний бодит байдлын дагуу ажилласаар, тодорхойгүй ч биш, ер бусын ч биш байдаг. Хүнийг хуучин зан чанараас нь бүрэн ангижруулахын тулд Бурхан хичээл чармайлтаа зориулан янз бүрийн өнцгөөс ярьж, хүмүүсийн жинхэнэ уг чанарыг ил болгож, дуулгаваргүй байдалд нь шүүлт хийн, нэг хоромд, хүн бүртэй харьцана гэж хэлээд, бүлэг хүмүүсийг аварна гэж дараагийн хоромд тунхагладаг; нэг бол хүмүүст шаардлага тавьж, эсвэл тэдэнд

анхааруулдаг; тэдний дотоод талыг ээлж дараалан задлан шинжилж, эмчилгээ хийдэг. Тиймээс Бурханы үгийн удирдамж дор, хүмүүс газар дэлхийн өнцөг булан бүр лүү аялж, цэцэг болгон нь хамгийн үзэсгэлэнтэй сайхан нь байхаар өрсөлддөг элбэг дэлбэг цэцэрлэгт орсон мэт байдаг. Бурхан яг л төмөр агуулсан юуг ч өөртөө татдаг соронзон мэт, Бурхан юу ч хэлсэн хүн төрөлхтөн Түүний үг рүү орно. “Хүмүүс Намайг ер хайхардаггүй тул Би ч бас тэднийг нухацтай авч үздэггүй. Тэд Надад ямар ч анхаарал хандуулдаггүй тул Би ч гэсэн тэдэн дээр шаргуу ажиллах хэрэггүй. Энэ нь хоёуланд нь хамгийн сайн биш гэж үү?” хэмээх үгийг уншаад Бурханы ардуудад ёроолгүй нүхэнд дахин хаягдсан мэт, эсвэл амин газар луугаа дахин цохиулсан мэт санагдаж, бүрмөсөн цочирдож орхидог. Тиймээс тэд арга барил руу дахин ордог. Тэд ялангуяа “Хаанчлал дахь Миний ардуудын нэг гишүүн болохын хувьд хэрвээ та нар үүргээ биелүүлж чадахгүй бол Надад жигшигдэн гологдоно!” хэмээх үгийн талаар будилдаг. Ихэнх хүн ихэд гомдсон учраас нулимс урсган, ийнхүү боддог: “Ёроолгүй нүхнээс авирч гарахад надад хэцүү байсан, иймээс хэрвээ би дахиад тийшээ унавал ямар ч найдваргүй болно. Би хүний ертөнцөөс юу ч олж аваагүй, амьдралдаа төрөл бүрийн бэрхшээл, зовлон туулсан. Ялангуяа итгэлтэй болсныхоо дараа би хайртай хүмүүстээ хаягдаж, гэр бүлийнхний хавчлага, нийгэм дэх хүмүүсийн гүжирдлэгийг туулсан ба дэлхий ертөнцийн аз жаргалаас алийг нь ч эдлээгүй. Хэрвээ би дахиад ёроолгүй нүх рүү унах юм бол миний амьдрал бүр ч хий дэмий болох бус уу?” (Хүн энэ талаар бодох тусам, төдий чинээ их гунигладаг.) “Би бүх итгэл найдвараа Бурханы гарт даатгасан. Хэрвээ Тэр намайг орхивол би яг одоо үхсэн нь дээр байх… За яах вэ, бүх зүйлийг Бурхан урьдчилан тогтоосон болохоор одоо би зөвхөн Бурханыг хайрлахаар эрэлхийлж л чадна, бусад бүх зүйл хоёрдугаарт байдаг. Яагаад миний хувь заяа ийм байгаа юм бэ?” Хүмүүс ингэж бодох тусам, Бурханы стандарт болон Түүний үгийн зорилгод улам их ойртдог. Ийм маягаар Түүний үгийн зорилго биелдэг. Бурханы үгийг харсныхаа дараа хүмүүс бүгд дотоод үзэл суртлын зөрчилдөөнийг туулдаг. Тэдний цорын ганц сонголт нь хувь заяаны тушаалд захирагдах явдал бөгөөд ийм маягаар Бурханы зорилго биелдэг. Бурханы үг хатуу байх тусам, үүний үр дүнд хүмүүсийн дотоод ертөнц улам төвөгтэй болдог. Энэ нь яг л шарханд хүрэхтэй адил; хэдий чинээ чанга хүрнэ, төдий чинээ их өвдөн, хүмүүс үхэл амьдралын хооронд эргэлдэж, бүр амьд үлдэх итгэл найдвараа алдах хэмжээнд хүрдэг. Ийм болохоор хүмүүс хамгийн их зовж, горьдлого тасарсан үедээ л үнэн зүрх сэтгэлээ Бурханд өгч чаддаг. Өчүүхэн төдий ч гэсэн найдлага үлдэх л юм бол тэд тусламж авахаар Бурхан руу явахын оронд жам ёсоороо амьд үлдэх бие даасан аргуудыг хэрэглэнэ, хүний уг чанар ийм л байдаг. Яагаад гэвэл, өөрийгөө зөвтгөдөг нь хүний уг чанар бөгөөд хүмүүс өөрөөсөө бусдыг дорд үзэх хандлагатай байдаг. Тиймээс Бурхан: “Тав тухтай байхдаа ганц ч хүн Намайг бас л хайрлаж чадаагүй; амар амгалан, аз жаргалтай байх үедээ баяр баясгалангаа хуваалцахаар ганц ч хүн Надад хандаагүй” гэж

хэлсэн юм. Энэ нь үнэхээр урам хугармаар; Бурхан хүнийг бүтээсэн боловч хүний ертөнцөд ирэх үед нь дэлхийгээр тэнүүчилдэг өнчин хүүхэд, эсвэл улс оронгүй дэлхийн хүн мэт Түүнийг хүмүүс эсэргүүцэж, нутаг дэвсгэрээсээ хөөн зайлуулахаар чармайдаг. Хэн ч Бурханд сэтгэл татагддаггүй, хэн ч Түүнийг үнэхээр хайрладаггүй, Түүнийг ирэхэд хэн ч, хэзээ ч угтан аваагүй. Харин ч Бурханы ирэхийг харах үедээ тэдний баяр хөөртэй царай нүд ирмэхийн төдийд барайж, гэнэтийн шуурга болох гэж байгаа мэт, Бурхан гэр бүлийнх нь аз жаргалыг булаан авч магадгүй мэт, Бурхан хүмүүсийг хэзээ ч ерөөгөөгүй, харин тэдэнд үргэлж золгүй явдал л авчирч байсан мэт байдаг. Тиймээс хүний оюун ухаанд, Бурхан бол ашиг тусгүй, харин өөрсдийг нь үргэлж хараадаг Нэгэн юм. Үүнээс үүдэн хүмүүс Түүнд анхаарал хандуулдаггүй, Түүнийг угтан авдаггүй; Түүнд үргэлж хүйтэн хөндий ханддаг бөгөөд үргэлж л ийм байсаар ирсэн. Хүмүүсийн зүрх сэтгэлд ийм зүйлс байдаг учраас Бурхан, хүн бол эрүүл ухаангүй, ёс суртахуунгүй, мөн хүмүүст байх учиртай мэдрэмжүүдийг ч тэднээс харах аргагүй гэж хэлдэг. Хүмүүс Бурханы мэдрэмжийг огт хайхардаггүй, харин Бурхантай харьцахын тулд “зөвт байдал” гэгчийг ашигладаг. Тэд олон жилийн турш ийм байсаар ирсэн бөгөөд энэ шалтгааны улмаас Бурхан, тэдний зан чанар өөрчлөгдөөгүй гэж хэлсэн юм. Тэд хэдхэн өдөөс хэтрэхгүй мөн чанартай гэдгийг энэ нь харуулдаг. Хүмүүс өөрсдийгөө эрхэмлэдэггүй учраас тэднийг ямар ч үнэ цэнгүй өөдгүй амьтад гэж хэлж болно. Тэд бүр өөрсдийгөө ч хайрладаггүй, харин ч өөрсөд дээрээ гишгэлдэг бол тэдний үнэ цэнгүй байдлыг энэ нь харуулж байгаа бус уу? Хүн бол өөрөөрөө тоглож, доромжлуулахын тулд өөрийгөө бусдад сайн дураараа өгдөг завхай эмтэй адилхан. Тэгсэн ч гэсэн хүмүүс хэчнээн дорд болохоо мөн л мэддэггүй. Бусдын төлөө ажиллаж, бусадтай ярилцан, бусдын хяналт дор өөрсдийгөө байлгах нь тэдэнд таатай байдаг; энэ нь яг үнэндээ хүний бузар муухай байдал бус уу? Хэдийгээр Би хүмүүсийн дундах амьдралыг мэдэрч, хүний амьдралыг үнэхээр туулаагүй ч хүний хөдөлгөөн, үйлдэл, үг, үйл хэрэг бүрийг тун тодорхой ойлгодог болсон. Тэгээд бүр заль мэхээ илчилж зүрхлэхээ больж, шунал тачаалдаа автахаа болих хүртэл нь хүмүүсийн сэтгэлийн гүн дэх ичгүүрийг ч илчилж чаддаг. Эмгэн хумс дун руугаа буцан шургадаг шиг тэд үзэшгүй муухай байдлаа илчилж зүрхлэхээ больдог. Хүмүүс өөрсдийгөө мэддэггүй учраас бусдын өмнө өөрсдийн увдисыг бэлхнээ гайхуулж, муухай төрхөө харуулдаг нь тэдний хамгийн том алдаа дутагдал юм; энэ бол Бурханы хамгийн их жигшдэг зүйл билээ. Учир нь хүмүүсийн хоорондох харилцаа хэвийн бус байдаг, хүмүүст хүн хоорондын хэвийн харилцаа дутагддаг, Бурхан, хүн хоёрын хооронд хэвийн харилцаа бүр ч байдаггүй. Бурхан маш ихийг хэлсэн бөгөөд ийн үйлдсэний гол зорилго нь хүмүүсийн зүрх сэтгэлд зай эзэлж, тэнд суурьшсан бүх шүтээнээс нь хүмүүсийг ангижруулах явдал юм. Тийнхүү Бурхан бүх хүн төрөлхтнийг захирч, газар дээр оршин тогтнох зорилгодоо хүрч чадна.

15-Р БҮЛЭГ

Бурхан, хүн хоёрын хоорондох хамгийн том ялгаа гэвэл Бурханы үг юуг ч нуулгүй, асуудлын голыг шууд хөнддөг. Иймээс Бурханы зан чанарын энэ талыг өнөөдрийн эхний өгүүлбэрээс харж болно. Энэ нь хүний үнэн төрхийг ил болгож, Бурханы зан чанарыг ил тод илчилдэг. Бурханы үгийн үр дүнд хүрч чадах хэд хэдэн талын эх сурвалж энэ юм. Гэвч хүмүүс үүнийг ухаарч чаддаггүй; тэд Бурханыг “задлан шинжлэлгүй” Бурханы үгээр дамжуулан үргэлж өөрсдийгөө л мэдэж авдаг. Тэд Бурханд халдахаас үхтлээ айж байгаа мэт, эсвэл “нухацтай байдлынх нь” төлөө Бурхан тэднийг хөнөөх мэт байдаг. Үнэндээ ихэнх хүн Бурханы үгийг эерэг бус, сөрөг өнцгөөс идэж уудаг. Одоо хүмүүс Бурханы үгийн удирдамж дор “даруу төлөв байж, захирагдахад анхаарч” эхэлсэн гэж хэлж болох юм. Хүмүүс Бурханы үгэнд ямар ч анхаарал хандуулахгүй байснаа хэтэрхий их анхаарал хандуулах болж өөр нэгэн туйлшрал руу явж эхэлсэн гэдэг нь үүнээс илэрхий байна. Гэхдээ ганц ч хүн эерэг өнцгөөс ороогүй, мөн хүмүүсийг Бурханы үгэнд анхаардаг болгох Бурханы зорилгыг хэн ч, хэзээ ч үнэхээр ухаараагүй. Бурхан чуулганы амьдралыг биечлэн туулах шаардлагагүйгээр чуулган дахь бүх хүний бодит байдлыг үнэн зөв, алдаа мадаггүй ойлгож чаддаг гэдэг нь Бурханы хэлсэн зүйлээс мэдэгддэг. Хүмүүс шинэ арга барил руу дөнгөж орсон болохоор сөрөг элементээсээ хараахан бүрэн ангижраагүй; хүүрийн үнэр чуулган даяар ханхалсаар л байгаа. Хүмүүс дөнгөж эм уучхаад мэл гайхсаар байгаа мэт, бүрэн ухаан ороогүй байдаг. Тэд одоо ч үхлийн заналхийлэл дор байгаа тул айдас хүйдэс дунд өөрсдийгөө даван гарч чадахгүй байгаа мэт байдаг. “Хүмүүс бүгд өөрсдийгөө таних чадваргүй бүтээлүүд”: Энэ үгийг хэлсэн байдал чуулганы байгуулалт дээр суурилсаар байдаг. Чуулган дахь хүмүүс бүгд Бурханы үгэнд анхаарал хандуулдаг ч гэлээ тэдний уг чанар гүнээ бугшмал, ангижрах аргагүй хэвээр үлддэг. Иймээс, хүмүүс бардамналынхаа дунд Түүний үгийн цохилтыг хүлээн авч чадна гэсэндээ Бурхан өмнөх үе шатанд хүмүүсийг шүүхийн тулд тийм маягаар ярьсан юм. Хэдийгээр хүмүүс ёроолгүй нүхэнд таван сарын цэвэршүүлэлт туулсан ч бодит байр байдал нь Бурханыг мэддэггүй хэвээр байна. Тэд одоо ч замбараагүй хэвээр; гагцхүү Бурханаас л арай илүү сэрэмжлэх болжээ. Энэ алхам бол Бурханы үгийг мэдэх замаар орохдоо хүмүүсийн хийдэг эхний зүй зохистой алхам билээ; иймд Бурханы үгийн мөн чанартай холбогдоход, ажлын өмнөх хэсэг өнөөдрийн замыг тавьсан, мөн одоо л бүх зүйл хэвийн болж байгаа гэдгийг харахад хэцүү биш. Хүмүүсийн хөнөөлт сул тал гэвэл хувийн эрх чөлөөг олж авч, байнгын хязгаарлалтаас зайлсхийхийн тулд Бурханы Сүнсийг махбодоос нь салгах хандлагатай байдаг. Иймээс Бурхан хүмүүсийг “цовоо хөгжүүн нисэж байгаа” бяцхан шувууд гэж дүрсэлдгийн шалтгаан энэ юм. Бүх хүн төрөлхтний бодит байдал ийм байдаг. Энэ л бүх хүнийг хамгийн амархан унагадаг бөгөөд энд л хүмүүс замаа алдах хамгийн их магадлалтай. Хүн төрөлхтний дундах Сатаны ажил ийм ажлаас цаашгүй гэдэг нь энд илэрхий байдаг. Сатан хүмүүст

үүнийг хийх тусам хүмүүст тавих Бурханы шаардлага улам хатуу чанд болдог. Тэрээр Өөрийнх нь үгэнд анхаарлаа хандуул гэж хүмүүсээс шаарддаг, харин Сатан үүнийг нураах гэж шаргуу ажилладаг. Гэвч Бурхан Өөрийнх нь үгэнд илүү их анхаарал хандуул гэж хүмүүст үргэлж сануулсаар ирсэн; энэ бол сүнсний ертөнцөд өрнөж буй дайны оргил цэг юм. Үүнийг ингэж хэлж болно: Бурханы хүнд хийхийг хүсдэг яг тэр зүйлийг Сатан устгахыг хүсдэг бөгөөд Сатаны устгахыг хүсдэг зүйл бүрэн илэрхий байдлаар, хүнээр дамжин илэрхийлэгддэг. Хүмүүст Бурханы хийдэг зүйлийн тодорхой жишээ бий: Хүмүүсийн нөхцөл байдал улам бүр сайжирч байгаа. Түүнчлэн Сатан хүн төрөлхтнийг сүйрүүлдгийн тодорхой төлөөлөл ч бий: Тэд улам бүр доройтон гажуудаж, нөхцөл байдал нь улам бүр дордож байна. Нөхцөл байдал нь дэндүү хүнд хэцүү болмогц тэд Сатанд олзлогдох боломжтой. Бурханы үгэнд харуулсан чуулганы бодит байдал энэ бөгөөд энэ нь бас сүнсний ертөнцийн бодит нөхцөл байдал юм. Энэ нь сүнсний ертөнцийн хөдөлгөөний тусгал билээ. Хэрэв хүмүүс Бурхантай хамтран ажиллах итгэлгүй бол Сатанд олзлогдох аюулд байдаг. Энэ бол баримт. Хэрэв хүмүүс зүрх сэтгэлээ Бурханд эзэмдүүлье хэмээн бүрэн өргөл болгож үнэхээр чаддаг бол яг л Бурханы хэлсэнчлэн “Миний өмнө байхдаа тэд Миний тэвэрт байгаа мэт, халуун дулаан байдлыг амсдаг.” Хүн төрөлхтөнд тавьдаг Бурханы шаардлага өндөр биш гэдгийг энэ нь харуулдаг; тэд өндийн босож, Бурхантай хамтран ажиллах нь л Түүнд хэрэгтэй байдаг. Энэ нь амархан, аз жаргалтай зүйл бус уу? Баатар болгоныг, агуу хүн бүрийг сандаргасан нэг зүйл энэ мөн үү? Генералуудыг байлдааны талбараас татан аваад, оронд нь нэхмэл хийлгэж байгаа мэт—энэ “баатрууд” бэрхшээлээс болоод хөдлөхөө больсон ба юу хийхээ мэддэггүй.

Хүн төрөлхтөнд тавьдаг Бурханы шаардлага аль талд хамгийн их байна, тэр тал дээр л хүмүүсийн эсрэг Сатаны дайралт хамгийн ширүүн байдаг тул бүх хүний байр байдал тийнхүү илчлэгддэг. “Миний өмнө зогсож байгаа та нараас хэн чинь орж буй цас шиг цэвэр, хаш мэт сэвгүй байх байсан бэ?” Бүх хүн Бурханыг аргалж, Түүнээс аливааг нуусаар л байдаг; тэд өөрсдийн онцгой явуулгыг хийсээр байгаа. Тэд Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд зүрх сэтгэлээ Бурханы гарт бүрэн даатгаагүй атлаа урам зоригтой байх замаар Бурханаас шагнал хүртэхийг хүсдэг. Хүмүүс амттай хоол идэх үедээ Бурханыг хойш тавьж, “зохицуулалт” хүлээлгэн тэнд зогсоож орхидог; сайхан хувцаслах үедээ хүмүүс гоо үзэсгэлэнгээ бахдан толины өмнө зогсдог бөгөөд зүрх сэтгэлийнхээ угт Бурханыг сэтгэл хангалуун байлгадаггүй. Зэрэг зиндаатай болох үедээ, үрэлгэн таашаалтай байх үедээ тэд байр сууриндаа залран, үүнийгээ эдэлж эхэлдэг хэр нь Бурханы өргөлтөөс үүдэн өөрсдийгөө даруухан болгодоггүй. Харин ч тэд өндөр байр сууриндаа зогсож, сүржин үгээ хэлээд Бурханы байгаад огт анхаарал хандуулдаггүй, Бурханы эрхэм нандин байдлыг мэдэхээр эрэлхийлдэг ч үгүй. Хүмүүс зүрх сэтгэлдээ шүтээнтэй байх үед, эсвэл зүрх сэтгэлээ хэн нэгэнд эзэмдүүлэх үед Бурхан тэдний зүрх сэтгэлд хөндлөнгийн этгээдээс цаашгүй мэтээр, Бурханы байгааг аль хэдийн

үгүйсгэсэн гэсэн үг юм. Бусдаас хүртдэг хайраа Бурханд булаалгах вий, тэгээд ганцаардах вий гэхээс тэд үхтлээ айдаг. Хүмүүс газар дэлхий дээрх юунаас ч болоод Бурханыг үл ойшоох ёсгүй, хүмүүсийн хооронд хайр сэтгэл байж болох ч энэ “хайраас” Бурханыг холдуулж болохгүй гэдэг нь Бурханы анхдагч санаа зорилго юм. Газар дэлхийн бүх зүйл—хүмүүсийн хооронд нүдэнд харагдаж, гарт баригддаггүй сэтгэл ч хий хоосон. Бурханы оршин тогтнол байхгүй бол бүх бүтээл ор мөргүй болох байсан юм. Газар дэлхий дээр, бүх хүнд хайрладаг зүйл гэж байдаг ч Бурханы үгийг хэн ч, хэзээ ч хайрладаг зүйлээ гэж үзсэн удаагүй. Хүмүүс Бурханы үгийг ойлгодог түвшнийг энэ нь тодорхойлдог. Хэдийгээр Бурханы үг хатуу боловч хэн ч үүнд шархалдаггүй, учир нь хүмүүс үүнд жинхэнээсээ анхаарал хандуулдаггүй; харин ч цэцэг ажиглаж байгаа мэт тэдгээрийг хардаг. Тэд Бурханы үгийг өөрсдийн амтлах жимс гэж үздэггүй тул Бурханы үгийн мөн чанарыг мэддэггүй. “Хэрвээ хүмүүс Миний илдний хурцыг үнэхээр харж чаддаг байсан бол харх адилаар нүх рүүгээ яаран харайлдах байсан юм.” Хэвийн хүний байр байдалтай нэгэн Бурханы үгийг уншсаныхаа дараа мэл гайхаж, ичгүүрт автан, бусдын нүүрийг харж чадахгүй байх байсан. Гэвч одоо хүмүүс яг эсрэгээрээ байдаг—тэд Бурханы үгийг бусдын эсрэг цохилт өгөх зэвсэг болгон ашигладаг. Тэд үнэхээр ичгүүр сонжуургүй!

Бурханы айлдвараар бид ийм байдалд хүрсэн: “Хаанчлалын дотор Миний амнаас айлдвар гараад зогсохгүй, Миний хөл бүх газар нутаг даяар хаа сайгүй албан ёсоор алхалдаг.” Бурхан, Сатан хоёрын хоорондох дайнд замын алхам тутамд Бурхан ялж байна. Тэрээр Өөрийн ажлыг орчлон ертөнц даяар өргөн хүрээнд өргөжүүлж буй бөгөөд Бурханы мөр, ялалтын тэмдэг хаа сайгүй байдаг гэж хэлж болно. Сатан явуулгаараа улс орнуудыг хагалан бутаргаж, Бурханы удирдлагыг сүйрүүлнэ гэж найддаг ч Бурхан бүхий л орчлон ертөнцийг газрын хөрснөөс арчих гэж биш, харин дахин зохион байгуулахын тулд энэхүү бутралыг ашигласан. Бурхан өдөр бүр шинэ зүйл хийдэг ч хүмүүс анзаараагүй. Тэд сүнсний ертөнцийн хөдөлгөөнд огт анхаарал хандуулдаггүй тул Бурханы шинэ ажлыг харж чаддаггүй. “Сансар огторгуй дотор Миний алдрын гэрэлд бүх зүйл шинэ мэт гялалзан, сэтгэл бахдуулж, хүмүүсийн сэтгэл санааг өргөм хөөр баяртай талыг харуулж, хүний төсөөлөл дэх Сатаны хөндлөнгийн оролцоогүй, гаднын дайснуудын халдлагаас ангид тэнгэрүүдийн цаадах тэнгэрт одоо оршин байгаа мэт байдаг.” Энэ нь газар дээрх Христийн хаанчлалын баяр баясгалант дүр зургийг зөгнөж, бас хүн төрөлхтөнд гурав дахь тэнгэрийн нөхцөл байдлыг танилцуулдаг: Сатаны хүчний ямар ч дайралтгүйгээр, Бурханд харьяалагддаг ариун зүйлс л тэнд оршдог. Гэхдээ Бурханы Өөрийн газар дээрх ажлын нөхцөлийг хүмүүст харуулах нь хамгийн чухал: Тэнгэр бол шинэ тэнгэр бөгөөд үүнийг даган газар ч мөн шинэчлэгддэг. Энэ нь Бурханы Өөрийн удирдамж доорх амьдрал тул хүмүүс бүгд хэмжээлшгүй аз жаргалтай байдаг. Тэдний ухамсарт, Сатан бол хүн төрөлхтний “хоригдол” бөгөөд Сатаны оршин тогтнолоос үүдэн тэд огтхон ч айж хулчийдаггүй.

Бурханлаг байдлын шууд заавар, удирдамжаас үүдэн Сатаны явуулга бүгд бүтэлгүйтсэн бөгөөд Сатан оршин тогтнохоо больж, Бурханы ажлаар газрын хөрснөөс арчигдсан гэдгийг нотлоход ч энэ нь хангалттай. Иймээс “тэнгэрүүдийн цаадах тэнгэрт оршин байгаа” гэдэг. “Ямар нэг үймээн самуун хэзээ ч гараагүй, сансар огторгуй ч хэзээ ч хуваагдаагүй” гэж Бурхан хэлэхдээ сүнсний ертөнцийн нөхцөл байдлыг хэлж байсан юм. Энэ нь Бурхан Сатаныг ялснаа тунхагладгийн нотолгоо, Бурханы эцсийн ялалтын тэмдэг билээ. Бурханы бодлыг нэг ч хүн өөрчилж чадахгүй, хэн ч үүнийг мэдэж чадахгүй. Хүмүүс Бурханы үгийг уншиж, нухацтай шинжилсэн ч мөн чанарыг нь илэрхийлэх чадваргүй хэвээр үлддэг. Жишээлбэл, “Би од мичдийн дээгүүр дүүлэн харайж, нар цацрагаа илгээх үед дулааныг нь сарниулж, галууны өд шиг том цасан ширхгийг гараасаа унагасан. Гэхдээ Намайг бодлоо өөрчлөхөд тэр бүх цас гол болон хайлаад, агшин зуур тэнгэрийн дор хаа сайгүй хавар болж, маргад ногоон өнгө газрын гадаргыг тэр чигт нь хувиргасан” гэж Бурхан хэлсэн. Хүмүүс энэ үгийг оюун санаандаа төсөөлж чаддаг байж болох ч Бурханы санаа зорилго тийм энгийн байдаггүй. Тэнгэрийн доорх хүн бүр мэл гайхаж байх үед Бурхан авралын дуу хоолойгоор айлдаж, улмаар хүмүүсийн зүрх сэтгэлийг сэрээдэг. Гэвч элдэв янзын гамшиг нүүрлэдэг учраас ертөнцийн цөвүүнийг тэд мэдэрдэг тул бүгд үхлийг эрэлхийлэн, хүйтэн, цэвдэг агуйд оршин байдаг. Тэд хүчтэй цасан шуурганы жаварт хөлдөөд, газар дэлхийн халуун дулаан дутмагаас үүдэн амьд үлдэж чадахгүйдээ тулдаг. Хүмүүс завхралаасаа л болоод нэг нэгнээ улам харгисаар хөнөөж байна. Чуулганд, хүмүүсийн дийлэнхийг агуу улаан луу ганц үмхээд залгих болно. Бүх шалгалт өнгөрсний дараа Сатаны үймээн арилна. Өөрчлөлтийн ид дунд бүхий л ертөнцөд хавар ийнхүү түгэж, газар дэлхийг халуун дулаан бүрхэж, дэлхий ертөнц эрч хүчээр дүүрнэ. Эдгээр нь бүхий л удирдлагын төлөвлөгөөний бүх алхам юм. Бурханы ярьсан “шөнө” нь Сатаны галзуурал оргилдоо хүрэх үеийг хэлдэг бөгөөд энэ нь шөнөөр тохиолдоно. Яг одоо ийм зүйл болж байгаа бус уу? Хүмүүс бүгд Бурханы гэрлийн удирдамж дор амьдардаг ч шөнийн харанхуйн зовлон шаналлыг туулж байгаа. Хэрэв тэд Сатаны хүлээсээс ангижирч чадахгүй бол үүрд харанхуй шөнөөр амьдрах болно. Газар дээрх улс орнуудыг хар: Бурханы ажлын алхмуудаас болоод газар дээрх улс орнууд “ийш тийш гүйлдэж”, дор бүрнээ “тохиромжтой хүрэх газраа эрж хайж” байна. Бурханы өдөр хараахан ирээгүй тул газар дээрх бүхэн ороо бусгаа байдалтай хэвээр байдаг. Бурхан бүхий л орчлон ертөнцөд ил тод харагдах үед Түүний алдар Сион уулыг бүрхэх бөгөөд Бурханы гараар зохицуулагдах тул бүх зүйл дэг журамтай, эмх цэгцтэй байх болно. Бурханы үг зөвхөн өнөөдрийг ярьдаг бус, маргаашийг ч бас зөгнөдөг. Өнөөдөр нь маргаашийн үндэс суурь, иймээс өнөөдрийн байдлаар Бурханы айлдварыг хэн ч бүрэн ойлгож чадахгүй. Бурханы үг бүрэн биелсний дараа л хүмүүс үүнийг бүрэн ойлгож чадна.

Бурханы Сүнс орчлон ертөнц дэх бүх орон зайг дүүргэдэг мөртөө бас бүх хүний дотор ажилладаг. Ийм болохоор хүмүүсийн зүрх сэтгэлд Бурханы бие хаа сайгүй

байгаа мэт, газар бүр Бурханы Сүнсний ажлыг агуулдаг мэт байдаг. Үнэндээ Бурхан махбодоор илэрсний зорилго нь Сатаны эдгээр үлгэр жишээг байлдан дагуулж, эцэст нь тэднийг олж авах явдал юм. Гэвч Сүнс махбодод ажиллах зууpаа энэ хүмүүсийг өөрчлөхийн тулд махбодтой бас хамтран ажиллаж байгаа. Бурханы үйл хэрэг ертөнц даяар өргөжиж, Бурханы Сүнс бүхий л орчлонг дүүргэдэг гэж хэлж болох ч Түүний ажлын алхмуудаас үүдэн муу хүмүүс шийтгүүлээгүйн зэрэгцээ сайныг үйлддэг хүмүүс шагнуулаагүй. Иймээс Бурханы үйл хэргийг газар дэлхийн бүх хүн магтаагүй. Тэрээр бүх зүйлийн дээр, бас дотор нь бий; түүнчлэн Тэрээр бүх хүний дунд бий. Бурхан үнэхээр оршин байдаг гэдгийг харуулахад энэ хангалттай. Бурхан бүх хүнд ил тод харагдаагүй учраас тэд: “Хүмүүсийн тухайд бол Би үнэхээр оршин байгаа мэт атлаа бас оршдоггүй мэт санагддаг” гэх мэт төөрөгдөлтэй болсон. Одоо Бурханд итгэдэг бүх хүнээс хэн нь ч Бурхан үнэхээр байдаг гэдэгт бүрэн дүүрэн, зуун хувь бат итгэдэггүй; бүгд жаран хувь эргэлзэж, дөчин хувь итгэдэг. Одоо хүн төрөлхтний байдал ийм байгаа юм. Өнөөгийн хүмүүс бүгд дараах байдалтай байдаг: Тэд Бурхан бий гэдэгт итгэдэг ч Бурханыг хараагүй; эсвэл Бурхан бий гэдэгт итгэдэггүй ч хүн төрөлхтөн шийдвэрлэж чадахааргүй олон бэрхшээлтэй байдаг. Тэгээд үргэлж л нэг юмтай ороцолдчихоод, үүнээсээ ангижирч чадахгүй байх шиг санагддаг. Хэдийгээр тэд Бурханд итгэдэг ч бага зэрэг тодорхойгүй байдлыг байнга мэдэрдэг мэт байдаг. Гэхдээ, хэрвээ итгэхгүй бол Бурхан үнэхээр оршин байдаг тохиолдолд хохирол амсах вий гэж тэд айдаг. Энэ нь тэдний хоёрдмол байдал юм.

“Миний нэрийн төлөө, Миний Сүнсний төлөө, Миний бүх удирдлагын төлөвлөгөөний төлөө хэн бүх хүч чадлаа зориулж чадах вэ?” Бас “Өнөөдөр, хаанчлал хүний ертөнцөд байгаа үе бол Би хүмүүсийн дунд биечлэн ирсэн үе юм. Миний оронд тулааны талбар луу айдас хүйдэсгүйгээр орж чадах нэгэн байна уу?” гэж Бурхан хэлсэн. Бурханы үгийн зорилго бол энэ: Махбод дахь Бурхан Өөрийн бурханлаг ажлыг шууд хийгээгүй бол, эсвэл бие махбодтой болохын оронд Тэрээр санваартнуудаар дамжуулан ажилласан бол агуу улаан лууг байлдан дагуулж хэзээ ч чадахгүй, хүмүүсийн дунд Хаан болон хаанчилж ч чадахгүй байх байлаа. Хүн төрөлхтөн бодит байдал дээр Бурханыг Өөрийг нь мэдэж чадахгүй тул Сатан хаанчилсаар л байх байсан юм. Иймээс ажлын энэ үе шатыг Бурхан махбод болсон биеэр биечлэн хийх ёстой. Хэрэв махбод өөрчлөгдсөн бол төлөвлөгөөний энэ үе шат хэзээ ч гүйцэлдэж чадахгүй, учир нь өөр махбодын ач холбогдол, мөн чанар адилхан биш байх байв. Хүмүүс энэ үгийн үгчилсэн утгыг л ойлгож чаддаг, учир нь Бурхан уг үндсийг нь ойлгодог юм. Бурхан: “Гэхдээ эцсийн эцэст, энэ нь чухамдаа Сүнсний ажил уу, эсвэл бие махбодын чиг үүрэг үү гэдгийг ойлгодог хүн нэг ч үгүй. Хүмүүс насан туршдаа нэгд нэггүй туулахад энэ нэг зүйл дангаараа хангалттай юм” хэмээсэн. Хүмүүс маш олон жилийн турш Сатаны завхралд өртсөн бөгөөд сүнслэг асуудлын талаарх ухамсраа аль эрт гээсэн. Иймээс Бурханы үгийн ганцхан өгүүлбэр хүмүүсийн нүдийг хужирлах мэт болдог. Сүнс ба сүнснүүдийн хоорондох

зайнаас болоод Бурханд итгэдэг бүх хүн Бурханыг хүсэн мөрөөсдөг бөгөөд Бурхантай илүү ойр дотно болж, зүрх сэтгэлээ уудлахад бүгд бэлэн байдаг. Гэвч тэд Бурхантай холбоо тогтоож зүрхлэлгүй, зүгээр л биширсэн хэвээр үлддэг. Энэ бол Сүнсэнд байдаг сэтгэл татах хүч юм. Бурхан бол хүмүүсийн хайрлах учиртай Бурхан бөгөөд Бурханд тэднээр хайрлуулах элемент хязгааргүй байдаг тул хүн бүр Бурханыг хайрлаж, хүн бүр Түүнд нууцаа итгэж хэлэхийг хүсдэг. Үнэндээ хүн бүр зүрх сэтгэлдээ Бурханыг гэх хайрыг тээж явдаг—харин Сатаны үймээнээс болоод л мэдрэмжгүй, ухаан муутай, хөөрхийлөлтэй хүмүүс Бурханыг мэдэж чаддаггүй. Ийм учраас Өөрийг нь гэх хүмүүсийн үнэн сэтгэлийн талаар Бурхан: “Хүмүүс зүрх сэтгэлийнхээ гүнд Намайг хэзээ ч жигшиж байгаагүй; харин ч сүснийхээ гүнд тэд Надаас салж яддаг билээ… Миний бодит байдал хүмүүсийг самгардуулж, мэл гайхуулж, алмайруулдаг хэр нь тэд үүнийг хүлээж авахад бэлэн байдаг” гэж хэлсэн юм. Бурханд итгэдэг хүмүүсийн зүрх сэтгэлийн гүн дэх бодит нөхцөл байдал энэ юм. Хүмүүс Бурханыг үнэхээр мэдэх үед Түүнд хандах хандлага нь аяндаа өөрчлөгддөг бөгөөд сүснийхээ чиг үүргээс үүдэн зүрх сэтгэлийнхээ гүнээс магтаал хэлж чаддаг. Бүх хүний сүнсний гүнд Бурхан байдаг ч Сатаны завхралын улмаас хүмүүс Бурханыг Сатантай андуурсан. Өнөөдөр Бурханы ажил яг энэ асуудлаас эхэлдэг бөгөөд эхнээсээ дуустлаа сүнсний ертөнц дэх тулааны төв байсаар ирсэн юм.

16-Р БҮЛЭГ

Хүний үзэл бодлоор бол Бурхан маш агуу, маш элбэг дэлбэг, тун гайхалтай, үнэхээр хэмжээлшгүй; хүмүүсийн нүдээр бол Бурханы үг өндөрт өргөгдөж, дэлхий ертөнцийн агуу шилдэг бүтээл мэт харагддаг. Гэвч хүмүүс хэтэрхий олон алдаа дутагдалтай, оюун санаа нь дэндүү энгийн, түүнчлэн хүлээн зөвшөөрөх чадвар нь хэтэрхий ядмаг учраас Бурхан Өөрийнхөө үгийг хэчнээн тодорхой хэлэхээс үл хамааран тэд сэтгэцийн өвчтэй мэт хөдөлгөөнгүй суусаар үлддэг. Өлсөх үедээ тэд юм идэх ёстой гэдгээ ойлгодоггүй, цангах үедээ юм уух ёстойгоо ойлгодоггүй; зүгээр л хашхирч, орилсоор байдаг ба сэтгэлийнх нь гүнд үгээр дүрслэхийн аргагүй зовлон бэрхшээл байгаа ч энэ тухай ярьж чадахгүй байгаа мэт байдаг. Бурхан хүн төрөлхтнийг бүтээх үед, хүн хэвийн хүн чанараар амьдарч, зөн совингийнхоо дагуу Бурханы үгийг хүлээн зөвшөөрөх нь Түүний санаа зорилго байлаа. Гэхдээ хамгийн анх хүн Сатаны уруу таталтад автсан учраас өнөөдөр өөрийгөө чөлөөлөх чадваргүй хэвээр байдаг бөгөөд хэдэн мянган жилийн туршид Сатаны хэрэгжүүлсэн зальжин арга мэхийг ялган таньж чаддаггүй. Үүний зэрэгцээ хүнд Бурханы үгийг бүрэн мэдэх эрхтэн дутмаг байдаг—энэ бүхэн нь өнөөдрийн нөхцөл байдалд хүргэсэн юм. Өнөөдрийн байдлаар хүмүүс Сатаны уруу таталтын аюул дор амьдарсаар байгаа тул Бурханы үгийг зөвөөр ойлгох чадваргүй хэвээр байдаг. Хэвийн хүмүүсийн зан чанарт шударга бус, зальжин байдал байдаггүй, хүмүүс бие биетэйгээ хэвийн

харилцаатай байдаг бөгөөд ганцаараа ажилладаггүй, амьдрал нь дундаж ч биш, доройтсон ч биш байдаг. Иймээс Бурхан бүгдийн дунд өргөмжлөгддөг; Түүний үг хүмүүсийн дунд тархаж, хүмүүс Бурханы халамж, хамгаалалт дор бие биетэйгээ амар жимэр амьдарч, Сатаны хөндлөнгийн оролцоогүйгээр газар дэлхий эв зохицлоор дүүрч, Бурханы алдар хүмүүсийн дунд хамгийн чухал байрыг эзэлдэг. Тийм хүмүүс тэнгэрэлчүүдтэй адил: цэвэр, цоглог, Бурханы талаар хэзээ ч гомдоллодоггүй бөгөөд өөрсдийн бүх хичээл чармайлтыг гагцхүү газар дээрх Бурханы алдрын төлөө зориулж байдаг. Одоо үе бол харанхуй шөнө—бүгд тэмтчин явж, эрж хайж байгаа, хав харанхуй шөнө тэднийг үхтэл нь айлгаж, тэд өөрийн эрхгүй дагжин чичирдэг; сайтар сонсвол баруун хойд зүгийн салхины улих чимээг хүний гашуудлын цурхиралт дагалдах мэт ажээ. Хүмүүс хувь заяаныхаа төлөө гуниглан уйлна. Тэд Бурханы үгийг уншдаг ч яагаад ойлгож чаддаггүй юм бэ? Тэдний амьдрал мухардлын ирмэг дээр байгаа мэт, тэднийг үхэл нөмрөх гэж буй мэт, тэдний сүүлчийн өдөр нүднийх нь өмнө байгаа мэт байдаг. Тийм өрөвдөлтэй нөхцөл байдал нь, эмзэг дорой тэнгэрэлчүүд Бурханыг дуудан хашхирч, ахин дахин шаналан уйлж зовлон бэрхшээлийнхээ талаар ярьдаг яг тэр мөч юм. Энэ шалтгааны улмаас Бурханы хөвгүүд, ардын дунд ажилладаг тэнгэрэлчүүд дахин хэзээ ч хүмүүс дээр бууж ирэхгүй; энэ нь, махан биед байх зуураа Сатаны ов мэхэнд автаж, өөрсдийгөө чөлөөлөх чадваргүй болохоос нь сэргийлэхийн төлөө байдаг тул тэд хүнд үл үзэгдэх сүнсний ертөнцөд л ажилладаг. Тиймээс, “Би хүмүүсийн зүрх сэтгэл дэх сэнтийд залрах үе бол Миний хөвгүүд, ардууд газар дэлхийг захирах мөч байх болно” хэмээн хэлэх үедээ Бурхан, газар дээрх тэнгэрэлчүүд тэнгэр дэх Бурханд үйлчилсний ерөөлийг эдлэх үеийг хэлж байгаа юм. Хүн тэнгэрэлчийн сүнсний илэрхийлэл учраас хүний хувьд газар дээр байх нь тэнгэрт байхтай адил; хүн газар дээрх Бурханд үйлчлэх нь тэнгэрэлчүүд тэнгэр дэх Бурханд шууд үйлчлэхтэй адил—тийнхүү газар дээр байх хугацаандаа хүн гуравдагч тэнгэрийн ерөөлийг эдэлдэг гэж Бурхан хэлсэн байдаг. Эдгээр үг нь үнэндээ ийм утгатай юм.

Бурханы үгэнд маш их утга нуугдаж байдаг. “Цаг нь ирэхэд хүмүүс Намайг зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэж, бодолдоо Намайг дурсан санана.” Энэ үг нь хүний сүнсэнд чиглэдэг. Эмзэг байдлаасаа болоод тэнгэрэлчүүд бүх зүйл дээр Бурханд үргэлж найддаг ба үргэлж Бурханд татагдаж, Бурханыг эрхэмлэн дээдэлсээр ирсэн. Гэвч Сатаны үймээн самуунаас болоод тэд өөрсдийгөө захирч, хянаж чаддаггүй; Бурханыг хайрлахыг хүсдэг боловч бүх зүрх сэтгэлээрээ Түүнийг хайрлаж чаддаггүй тул тэд зовж шаналдаг. Бурханы ажил тодорхой хэмжээнд хүрэх үед л эдгээр хөөрхийлөлтэй тэнгэрэлчийн Бурханыг үнэхээр хайрлах хүсэл биелж чадна, ийм учраас Бурхан тэр үгийг хэлсэн юм. Тэнгэрэлчүүдийн уг чанар нь Бурханыг хайрлаж, нандигнаж, дуулгавартай дагах явдал, гэсэн ч тэд үүнийг газар дээр биелүүлж чадахгүй байсаар ирсэн бөгөөд өнөөг хүртэл тэвчихээс өөр аргагүй байжээ. Та нар өнөөдрийн дэлхий ертөнцийг харж болно: Бүх хүний зүрх сэтгэлд

нэг Бурхан байдаг ч өөрсдийнх нь зүрх сэтгэлд байдаг Бурхан жинхэнэ үү, эсвэл хуурамч уу гэдгийг хүмүүс ялган таньж чаддаггүй бөгөөд хэдий тэд өөрсдийн энэ Бурханыг хайрладаг ч Бурханыг үнэхээр хайрлаж чаддаггүй, энэ нь тэд өөрсдийгөө огт хянаж чаддаггүй гэсэн үг юм. Бурханы илчилсэн, хүний муухай төрх бол сүнсний ертөнц дэх Сатаны жинхэнэ нүүр царай юм. Хүн анхнаасаа гэмгүй, нүгэлгүй байсан, тиймээс хүний бүх завхарсан, муухай байдал нь сүнсний ертөнц дэх Сатаны үйлдэл бөгөөд сүнсний ертөнцийн хөгжлийн үнэн зөв бичлэг билээ. “Өнөөдөр хүмүүс чадвартай болсон ба Миний өмнүүр маадайн алхаж, Надтай огтхон ч эрээ цээргүй инээж, марзганан Надтай ижил зиндааных мэт харилцаж болно гэж итгэдэг. Хүн Намайг бас л мэддэггүй, бид уг чанартаа адилхан, хоёулаа мах, цуснаас бүтсэн, хоёулаа хүний ертөнцөд оршдог гэж бодсоор байдаг.” Энэ нь хүний зүрх сэтгэлд Сатаны хийсэн зүйл юм. Сатан Бурханыг эсэргүүцэхийн тулд хүний үзэл болон энгийн нүдийг ашигладаг атал хүнийг эндхийн аюул гамшгаас зайлуулахын тулд Бурхан эдгээр үйл явдлыг хоёрдмол утгагүйгээр хүнд хэлдэг. Бүх хүний аюулт сул тал гэвэл тэд зөвхөн “мах, цуснаас бүрдсэн биеийг хардаг боловч Бурханы Сүнсийг хардаггүй.” Энэ бол Сатан хүнийг аргадаа оруулдаг үндсэн нэг тал юм. Махан бие дэх Сүнсийг л Бурхан гэж нэрлэж болно хэмээн бүх хүн боддог. Сүнс махбод болж, өөрсдийнх нь нүдний өмнө бодитоор гарч ирсэн гэж өнөөдөр хэн ч боддоггүй; хүмүүс Бурханыг “хувцас ба махбод” гэсэн хоёр хэсэг гэж хардаг ба хэн ч Бурханыг махбод болсон Сүнс гэж хардаггүй, хэн ч махбодын мөн чанарыг Бурханы зан чанар гэж үздэггүй. Хүмүүсийн төсөөллөөр Бурхан тун хэвийн байдаг боловч энэхүү хэвийн байдалд Бурханы гүн гүнзгий ач холбогдлын нэг тал нуугддаг гэдгийг тэд мэддэггүй гэж үү?

Бурхан бүхий л дэлхий ертөнцийг бүрхэж эхлэх үед хав харанхуй болсон бөгөөд хүмүүсийг унтаж байхад энэ боломжийг ашиглаад Бурхан хүмүүсийн дунд бууж, газар дэлхийн бүх өнцөг булан руу Сүнсийг албан ёсоор илгээж эхлэн, хүн төрөлхтнийг аврах ажлыг эхлүүлсэн юм. Бурхан махбодын дүртэй болж эхэлсэн ба газар дээр биечлэн ажилласан гэж хэлж болно. Дараа нь Сүнсний ажил эхэлж, газар дээрх бүх ажлыг албан ёсоор эхлүүлсэн. Хоёр мянган жилийн турш Бурханы Сүнс үргэлж орчлон ертөнц даяар ажилласан. Хүмүүс үүнийг мэдээгүй, бас мэдрээгүй боловч эцсийн өдрүүдэд энэхүү эрин үе удахгүй төгсөх гэж байх үед Бурхан биечлэн ажиллахаар газар дээр бууж ирсэн юм. Энэ бол эцсийн өдрүүдэд төрсөн бөгөөд махбодод амьдарч байгаа Бурханы дүрийг өөрийн биеэр харж чаддаг хүмүүсийн ерөөл билээ. “Оёоргүй гүний гадаргуу бүхэлдээ булингартсан байхад хүмүүсийн дунд Би дэлхий ертөнцийн гашуун зовлонг амсаж эхэлсэн. Миний Сүнс дэлхий даяар аялж, бүх хүний зүрх сэтгэлийг шинждэг, гэхдээ Би бас Өөрийн махбод болсон биеэр хүн төрөлхтнийг байлдан дагуулдаг.” Энэ нь тэнгэр дэх Бурхан болон газар дахь Бурханы хоорондох эв зохицолтой хамтын ажиллагаа юм. Эцсийн эцэст, газар дахь Бурхан бол тэнгэр дэх Бурхан, тэнгэр газар болон тэдгээрийн дундах бүх зүйлийг газар дээрх Бурхан бүтээсэн, хүнийг газар дээрх

Бурхан хянадаг, газар дээрх Бурхан тэнгэр дэх ажлыг газар дээр хийдэг, мөн тэнгэр дэх Бурхан махбодоор илэрсэн гэж хүмүүс оюун бодолдоо бодно. Энэ бол газар дээрх Бурханы ажлын эцсийн зорилго тул энэхүү үе шат нь махбодтой үеийн ажлын хамгийн өндөр стандарт юм; үүнийг бурханлаг чанараар гүйцэтгэж, бүх хүнийг үнэн сэтгэлээсээ үнэмшихэд хүргэдэг. Хүмүүс өөрсдийн үзэл дэх Бурханыг эрж хайх тусам, газар дээрх Бурхан бол бодитой биш гэж төдий чинээ их санагддаг. Тиймээс хүмүүс Бурханыг хоосон үг, сургаал дундаас эрж хайдаг гэж Бурхан хэлдэг. Хүмүүс өөрсдийн үзэл дэх Бурханыг хэдий чинээ их мэднэ, эдгээр үг болон хоосон сургаалыг ярихдаа төдий чинээ сурамгай болж, төдий чинээ их биширмээр болдог; хүмүүс үг болон хоосон сургаалыг ярих тусмаа Бурханаас улам холдож, хүний гол чанарыг төдий чинээ мэдэх чадваргүй болж, Бурханд улам дуулгаваргүй болж, Бурханы шаардлагаас улам холдон оддог. Хүнд тавих Бурханы шаардлага нь хүмүүсийн төсөөлдөг шиг ер бусын биш атал хэн ч, хэзээ ч Бурханы хүслийг үнэхээр ойлгож байгаагүй, тиймээс Бурхан “хүмүүс хязгааргүй тэнгэр, давлагаалах далай тэнгис, дөлгөөн нуур, аль эсвэл хоосон бичиг үсэг, номлол дундаас л эрж хайдаг” хэмээн хэлсэн байдаг. Бурхан хүнд шаардлага тавих тусам, Бурхан бол хүрэхийн аргагүй гэдгийг хүмүүс улам мэдэрч, Бурхан агуу гэдэгт улам их итгэдэг. Тиймээс тэдний ухамсарласнаар бол Бурханы амнаас гарсан бүх үг хүний хувьд хүршгүй байдаг тул Бурхан биечлэн ажиллахаас өөр аргагүй болдог; харин хүнд Бурхантай хамтран ажиллах өчүүхэн төдий ч дур хүсэл байдаггүй ба зүгээр л толгой бөхийн, нүглээ улайж, даруухан, дуулгавартай байхаар хичээн зүтгэдэг. Тийм болохоор хүмүүс өөрийн мэдэлгүй шинэ шашин руу, шашны сүмүүдэд байдгаас ч илүү туйлширсан шашны зан үйл рүү ордог. Энэ нь, сөрөг байдлаас эерэг байдал руу өөрчлөгдсөнөөр хэвийн нөхцөл байдалд эргэн очихыг хүмүүсээс шаарддаг; эс бөгөөс хүн улам илүү гүн урхидуулна.

Бурхан маш олон айлдвартаа уул, усыг дүрслэхэд яагаад анхаардаг вэ? Эдгээр үгэнд бэлгэдлийн утга учир байдаг уу? Бурхан хүнд махбод дахь үйл хэргээ харуулаад зогсохгүй, бас огторгуй дахь Түүний хүч чадлыг ойлгох боломж олгодог. Ийм маягаар, энэ бол махбод дахь Бурхан гэдэгт эргэлзэлгүй итгэхийн зэрэгцээ хүмүүс бас бодитой Бурханы үйл хэргийг мэдэж авдаг, тиймээс газар дээрх Бурханыг тэнгэр лүү илгээж, тэнгэр дэх Бурханыг газар луу доош авчирдаг, үүний дараа л хүмүүс Бурханыг юу болохыг бүгдийг нь харж, Бурханы бүхнийг чадагч байдлын талаар илүү их мэдлэгтэй болж чаддаг. Бурхан хүн төрөлхтнийг махбодоор байлдан дагуулж, бүхий л орчлон ертөнц даяар болон үүн дээгүүр аялахын тулд махбодыг даван гарч чаддаг байх тусам хүмүүс бодитой Бурханыг харсныхаа үндсэн дээр Бурханы үйл хэргийг төдий чинээ харж чаддаг ба тийнхүү бүхий л орчлон ертөнц даяарх Бурханы ажлын үнэн зөв байдлыг, энэ нь худлаа биш харин бодит гэдгийг мэддэг—иймээс тэд өнөөдрийн бодитой Бурхан нь хүний махан биетэй адил төрлийнх биш, харин Сүнсний биелэл гэдгийг мэдэж авдаг. Тиймээс Бурхан “Гэвч Миний уур хилэн бадрахад уулс тэр даруй хагаран

хуваагдаж, газар тэр даруй доргин чичирч, ус нэн даруй ширгэж, хүнийг гай гамшиг даруй хүрээлдэг” гэж хэлдэг. Хүмүүс Бурханы үгийг унших үедээ Бурханы махан биетэй холбогддог тул сүнсний ертөнц дэх үг болон ажил махбод дахь Бурхан руу шууд заадаг ба энэ нь илүү сайн үр дүнд хүргэдэг. Бурханыг ярих үед энэ нь ихэнхдээ тэнгэрээс газар луу, дараа нь дахин нэгэнтээ газраас тэнгэр лүү байдаг ба бүх хүнийг Бурханы үгийн сэдэл, эх үүсвэрийг ухаарах чадваргүй болгож орхидог. “Намайг тэнгэрүүдийн дунд байхад Миний байгаагаас болж одод хэзээ ч сандарч байгаагүй. Харин тэд зүрх сэтгэлээ Миний төлөөх ажилдаа зориулдаг.” Энэ нь тэнгэрийн байдал юм. Бурханд үйлчилдэг бүх зарц нар Бурханы төлөө өөрсдийн ажлыг хийхийн хамтаар Бурхан гуравдагч тэнгэрт бүх зүйлийг дэс дараалалтайгаар зохицуулдаг. Бурханы хэлснээр, тэд Бурханд дуулгаваргүй зүйл хэзээ ч хийж байгаагүй тул сандардаггүй, харин зүрх сэтгэлээ ажилдаа зориулдаг; тэнд хэзээ ч эмх замбараагүй байдал байдаггүй, тиймээс бүх тэнгэрэлч Бурханы гэрэлд амьдардаг. Харин тэгэхэд дуулгаваргүй байдлынхаа улмаас, Бурханыг мэддэггүйнхээ улмаас газар дээрх хүмүүс бүгд харанхуйд амьдардаг бөгөөд Бурханыг хэдий чинээ эсэргүүцнэ, төдий чинээ харанхуйд амьдардаг. Бурхан: “Тэнгэрүүд гэрэлтэй байх тусам доорх газар дэлхий төдий чинээ харанхуй байдаг” хэмээн хэлэх үедээ Бурханы өдөр бүх хүн төрөлхтөнд улам ойртож буйг хэлж байгаа юм. Тиймээс гуравдагч тэнгэр дэх Бурханы 6,000 жилийн завгүй байдал удалгүй төгсөнө. Газар дээрх бүх зүйл эцсийн бүлэгт орсон ба удалгүй нэг бүрчлэн Бурханы гараас таслагдана. Хүмүүс эцсийн өдрүүдийн цаг үе рүү цаашлан явах тусмаа хүний ертөнцийн завхралыг улам их амсаж чаддаг; эцсийн өдрүүдийн цаг үе рүү цаашлан явах тусмаа өөрсдийн махан биеийг улам их өөгшүүлдэг. Дэлхий ертөнцийн хөөрхийлөлтэй байдлыг өөрчлөхийг хүсдэг хүн бүр ч олон байдаг мөртөө Бурханы үйл хэргээс болоод шүүрс алдан итгэл найдвараа гээдэг. Тиймээс хүмүүс хаврын урин дулааныг мэдрэх үед Бурхан нүдийг нь халхалдаг тул тэд долгилох давлагаан дээр хөвж, нэг нь ч алс холын аврах завинд хүрч чаддаггүй. Хүмүүс төрөлхийн сул дорой учраас аливааг өөрчилж чадах хэн ч байхгүй гэж Бурхан хэлдэг. Хүмүүс итгэл найдвараа алдах үед Бурхан бүхий л орчлон ертөнцөд хандан ярьж эхэлдэг. Тэрээр бүх хүн төрөлхтнийг аварч эхэлдэг бөгөөд үүний дараа л хүмүүс, юмс өөрчлөгдмөгц бий болдог шинэ амьдралыг эдэлж чаддаг. Өнөөдрийн хүмүүс өөрсдийгөө хуурах үе шатанд байгаа. Тэдний өмнөх зам маш зэлүүд, бүдэг, ирээдүй нь “хэмжээлшгүй”, “зах хязгааргүй” байдаг учраас энэ эрин үеийн хүмүүс тэмцэх хүсэлгүй байдаг бөгөөд өдөр хоногийг Ханхао шувуу[a] шиг өнгөрүүлдэг. Амьдралыг, хүний амьдралын тухай мэдлэгийг нухацтай эрэлхийлсэн хэн ч хэзээ ч байгаагүй; харин ч тэд дэлхий ертөнцийн хөөрхийлөлтэй байдлыг

[a] Ханхао шувууны түүх нь шоргоолж, царцаа хоёрын тухай Эзопын ёгт үлгэртэй тун адилхан. Ханхао шувуу өөрийн хөрш, алаг шаазгайн олон удаагийн анхааруулгыг үл харгалзан, цаг агаар дулаахан байх зуур үүрээ барихын оронд унтахыг илүүд үздэг. Өвөл болоход уг шувуу хөлдөж үхдэг.

өөрчлөхийн тулд тэнгэр дэх Аврагч гэнэтхэн бууж ирэх өдрийг хүлээдэг ба үүний дараа л тэд үнэн сэтгэлээсээ амьдрахаар оролдоно. Энэ нь бүх хүн төрөлхтний жинхэнэ байр байдал, бүх хүний сэтгэхүй билээ.

Өнөөдөр Бурхан, хүний одоогийн сэтгэхүйг харгалзан үзээд ирээдүйн шинэ амьдралыг нь зөгнөдөг. Энэ нь Бурханы ярьдаг сүүмэлзэх гэрэл юм. Бурханы зөгнөдөг зүйл бол эцэст нь Бурханы биелүүлэх зүйл бөгөөд энэ нь Сатаныг ялсан Бурханы ялалтын үр жимс билээ. “Би бүх хүний дээгүүр явж, хаа сайгүй харж байна. Ямар ч зүйл хуучин харагдахгүй, ямар ч хүн урьдынх шигээ байхгүй. Би сэнтийдээ амарч, бүхий л орчлон ертөнцийн дээр налан…” Энэ бол Бурханы өнөөгийн ажлын үр дүн юм. Бурханы сонгосон бүх хүн анхдагч байдалдаа буцан очдог бөгөөд үүнээс үүдэн, маш олон жилийн турш зовсон тэнгэрэлчүүд чөлөөлөгддөг, яг л Бурханы хэлсэнчлэн “тэдний царай хүний зүрх сэтгэлд орших ариун нэгнийхтэй адилхан байдаг.” Тэнгэрэлчүүд газар дээр ажиллаж, газар дээр Бурханд үйлчилж, Бурханы алдар дэлхий даяар тархдаг учраас тэнгэрийг газар луу авчирч, газрыг тэнгэр лүү өргөдөг. Тиймээс хүн бол тэнгэр, газрыг холбодог холбоос юм; цаашид тэнгэр, газар тусдаа, салангид байхаа болиод, харин нэг болж холбогддог. Дэлхий ертөнц даяар Бурхан, хүн хоёр л оршин байдаг. Ямар ч тоос шороо, хир буртаг үгүй бөгөөд бүх зүйл шинэчлэгдэн, яг л бяцхан хурга тэнгэрийн доорх ногоон зүлгэн дээр хэвтэж, Бурханы бүх нигүүлслийг эдэлж буйтай адил байдаг. Ногоон өнгө хүрэлцэн ирснээс үүдэн амийн амьсгал гялалздаг, учир нь Бурхан үүрд мөнх хүнтэй хамт амьдрахаар дэлхий ертөнцөд ирдэг, яг л Бурханы хэлсэнчлэн “Би Сиондоо дахин нэгэнтээ амар тайван амьдарч чадна.” Энэ бол Сатаны ялагдлын бэлгэ тэмдэг, Бурханы амралтын өдөр бөгөөд энэ өдрийг бүх хүн шагшин магтаж, тунхаглаж, тэмдэглэнэ. Бурхан сэнтий дээрээ амрах үе нь бас Бурхан газар дээрх ажлаа дуусгах үе бөгөөд Бурханы бүх нууцыг хүнд харуулах яг тэр мөч юм; Бурхан, хүн хоёр үүрд эв найртай байж, хэзээ ч хагацахгүй—энэ бол хаанчлалын үзэсгэлэнтэй сайхан дүр зураг билээ!

Нууцуудын дотор нууц нуугдаж байдаг; Бурханы үг үнэхээр гүн гүнзгий агаад ойлгохын аргагүй!

17-Р БҮЛЭГ

Үнэндээ Бурханы амнаас гардаг бүх айлдвар хүмүүст мэдэгддэггүй; тэдгээр нь бүгд хүмүүсийн сонсож байгаагүй хэл юм. Тийм болохоор, Бурханы үг бол өөрөө нууц гэж хэлж болно. Нууцууд нь, хүмүүсийн үзэл баримтлалаараа хүрч чаддаггүй зүйлс, одоо хүмүүст Бурханы мэдэгддэг тэнгэрийн хэрэг явдлууд, эсвэл сүнсний ертөнцөд Бурханы хийдэг зүйлсийн тухай үнэнийг л агуулдаг гэж ихэнх хүн эндүүрэн боддог. Хүмүүс Бурханы бүх үгэнд эн тэнцүү ханддаггүй, мөн тэдгээрийг нандигнадаггүй; харин ч “нууцууд” хэмээн боддог зүйлдээ анхаарлаа төвлөрүүлдэг

гэдэг нь үүнээс илэрхий харагддаг. Хүмүүс Бурханы үг юу болохыг, эсвэл нууцууд юу болохыг мэддэггүй; өөрсдийнхөө үзлийн цар хүрээн дотор л Бурханы үгийг уншдаг гэдгийг энэ нь нотолдог. Бодит байдал дээр Бурханы үгийг үнэхээр хайрладаг ганц ч хүн байхгүй бөгөөд “хүмүүс Намайг мэхлэхдээ гарамгай” хэмээн Бурхан хэлсний уг үндэс яг энэ юм. Хүмүүс ямар ч ач гавьяагүй, эсвэл туйлын замбараагүй гэж Бурхан хэлдэг юм биш; энэ нь хүн төрөлхтний бодит нөхцөл байдлыг дүрсэлдэг. Өөрсдийнх нь зүрх сэтгэлд Бурханы үнэндээ хэр их зай эзэлдгийг хүмүүс өөрсдөө ч тийм тодорхой мэддэггүй; Бурхан Өөрөө л үүнийг бүрэн мэдэж байдаг. Тиймээс яг одоо хүмүүс хөхүүл хүүхэд шиг байдаг. Яагаад сүү уудгаа, юуны төлөө амьдрах ёстойгоо тэд огт мэддэггүй. Нялх хүүхдийн хэрэгцээг ээж нь л ойлгодог; ээж нь түүнийг өлсгөж үхүүлэхгүй, үхтэл нь их идүүлэх ч үгүй. Бурхан хүмүүсийн хэрэгцээг хамгийн сайн мэддэг болохоор заримдаа Түүний хайр үгэнд нь биеллээ олж, хааяа Түүний шүүлт үгэнд нь илчлэгдэж, зарим үед Түүний үг хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг шархлуулдаг, заримдаа энэ нь үнэн сэтгэлийн, чин үнэнч байдаг. Энэ нь хүмүүст, Түүний эелдэг байдлыг болон Түүнд хүрч болохуйц гэдгийг мэдрүүлдэг, мөн Тэр бол хүрч болшгүй төсөөллийн, сүрлэг хүн биш гэдгийг мэдрүүлдэг. Тэрээр хүмүүсийн оюун ухаанд байдаг, нүүр лүү нь шууд харж болдоггүй Тэнгэрийн Хүү ч биш, хүмүүсийн төсөөлдөг шигээр гэмгүй хүнийг хөнөөдөг зандалчин бүр ч биш. Бурханы бүхий л зан чанар Түүний ажилд илчлэгддэг; өнөөдрийн махбод дахь Бурханы зан чанар нь мөн л Түүний ажлаар дамжуулан биеллээ олдог. Тиймээс Түүний үйлчлэл бол гаднаа Тэр юу хийдэг, эсвэл хэрхэн харагддаг нь биш, харин үгийн үйлчлэл билээ. Эцэстээ хүн бүр Бурханы үгээр босгон байгуулагдаж, тэдгээрээс үүдэн бүрэн төгс болгуулна. Бурханы үгээр замчлуулаад хүмүүс өөрсдийн туршлагаар хэрэгжүүлэлтийн замыг олж авах бөгөөд Бурханы амнаас гарсан үгээр дамжуулан бүхий л зан чанарыг нь мэдэж авна. Үгээс нь үүдэн Бурханы бүх ажил биелж, хүмүүс амьдарч, бүх дайсан ялагдана. Энэ бол үндсэн ажил бөгөөд хэн ч үл ойшоож болохгүй. Бурханы үгийг харцгаая: “Миний айлдварууд аянга шиг нүргэлж, дөрвөн зүг найман зовхис, даян дэлхийг гэрэлтүүлдэг бөгөөд аянга цахилгаан дунд хүмүүс цохигдон унадаг. Аянга цахилгаан дунд нэг ч хүн бат зогссон нь үгүй; Миний гэрэл ирэхэд ихэнх хүн ухаан алдталаа айж, яах учраа олдоггүй.” Бурханыг амаа ангаймагц үг зүгээр л урсан гардаг. Тэрээр бүх зүйлийг үгээр гүйцэлдүүлж, бүх зүйл Түүний үгээр хувирч өөрчлөгддөг ба хүн бүр Түүний үгээр дамжуулан шинэчлэгддэг. “Аянга цахилгаан” гэдэг нь юуг хэлдэг вэ? Мөн “гэрэл” гэж юуг хэлдэг вэ? Бурханы үгээс зугтаж чадах ганц ч зүйл байхгүй. Тэрээр хүмүүсийн оюун ухааныг ил болгож, муу муухай байдлыг нь дүрслэхийн тулд үг ашигладаг; хүмүүсийн хуучин уг чанартай харьцаж, Өөрийн бүх ардыг бүрэн төгс болгохын тулд үг ашигладаг. Энэ нь яг Бурханы үгийн ач холбогдол биш гэж үү? Бүхий л орчлон ертөнц дээр Бурханы үгийн тусламж, дэмжлэг байгаагүй бол бүх хүн төрөлхтөн оршин тогтнохоо болих хэмжээнд аль хэдийн устгагдчих байлаа. Энэ бол Бурханы хийдэг зүйлийн зарчим бөгөөд зургаан

мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнийхөө үеэр Түүний ажилладаг арга барил юм. Энэ нь Бурханы үгийн ач холбогдлыг харуулдаг. Тэдгээр нь хүмүүсийн сэтгэлийн гүн рүү шууд нэвтэрдэг. Түүний үгийг хармагцаа хүмүүс гайхан балмагдаж, айдаст автаж, яаран зугтдаг. Тэд Түүний үгийн бодит байдлаас зугтахыг хүсдэг ба ийм учраас энэ “дүрвэгчдийг” хаа сайгүй харж болно. Бурханыг үгээ айлдмагц хүмүүс шилээ харуулан зугтаадаг. Энэ бол Бурханы дүрслэн өгүүлдэг, хүн төрөлхтний муу муухай төрхийн нэг тал юм. Яг одоо бүх хүн ухаан алдсан байдлаасаа аажмаар сэрж байна; урьд нь тэд бүгд сэтгэцийн өвчтэй байсан мэт байдаг—одоо Бурханы үгийг хараад тэд тэрхүү өвчнөөс үлдсэн үр дагаврыг туулж байгаа мэт санагддаг бөгөөд хуучин байдалдаа эргэн орж чаддаггүй. Хүмүүс үнэндээ ийм байдаг бөгөөд энэ нь бас “Энэ өчүүхэн гэрэлд сэтгэл хөдөлсөн олон хүн өөрсдийн хий хоосон санаанаас даруй сэрнэ. Гэвч газар дэлхий дээр Миний гэрэл буух өдөр ирснийг хэн ч, хэзээ ч ухаараагүй” гэх үгийн жинхэнэ дүрслэл юм. Ийм учраас Бурхан: “Гэрэл гэнэт ирэхэд хүмүүсийн дийлэнх олонх нь мэл гайхаж, цэл хөхөрдөг” хэмээн хэлсэн юм. Ингэж хэлэх нь тун зохистой. Хүн төрөлхтний талаарх Бурханы дүрслэл зүү орох зай ч үлдээдэггүй, Тэрээр үүнийг үнэхээр яг таг, алдаа мадаггүйгээр илэрхийлсэн, ийм учраас бүх хүн бүрэн үнэмшдэг. Түүнчлэн, өөрийн мэдэлгүйгээр Бурханыг гэх хайр тэдний зүрх сэтгэлийн гүнд өсөн нэмэгдэж эхэлсэн. Ийм маягаар л хүмүүсийн зүрх сэтгэл дэх Бурханы байр суурь улам бүр жинхэнэ болдог ба энэ нь бас Бурханы ажилладаг нэг арга зам юм.

“Хүмүүсийн дийлэнх олонх нь ердөө л балмагддаг; гэрэлд нүд нь шархалж, шаварт хаягддаг.” Тийм хүмүүс Бурханы хүслийн эсрэг явдаг (өөрөөр хэлбэл, Бурханыг эсэргүүцдэг) учраас Түүний үг ирэх үед тэрслүү байдлынхаа улмаас гэсгээлт амсдаг; ийм учраас тэднийг гэрэлд нүд нь шархалдаг гэж хэлсэн юм. Ийм төрлийн хүнийг аль хэдийн Сатанд өгчихсөн; иймээс шинэ ажилд орох үед тэдэнд гэгээрэл ч байдаггүй, гэрэлтүүлэлт ч байдаггүй. Ариун Сүнсний ажилгүй бүх хүн Сатанд эзэмдүүлсэн бөгөөд зүрх сэтгэлийнх нь гүнд Бурханд зориулсан ямар ч орон зай байдаггүй. Тиймээс энэ хүмүүс “шаварт хаягддаг” гэж хэлсэн. Ийм нөхцөл байдалд байгаа хүмүүс бүгд эмх замбараагүй байдалтай байдаг. Тэд зөв замд орж чаддаггүй, хэвийн байдалдаа буцан орж ч чаддаггүй; бүх бодол нь эсрэг байдаг. Сатан газар дээрх бүх хүнийг туйлын их завхруулсан. Хүмүүст ямар ч эрч хүч байдаггүй ба цогцосны үнэр ханхлуулж байдаг. Газар дээрх бүх хүн нянгийн тахал дунд амь зуудаг бөгөөд хэн ч үүнээс зугтаж чадахгүй. Тэд газар дээр амь зуухыг хүсдэггүй боловч ямар нэгэн томоохон зүйл тохиолдохыг хүмүүс нүдээр үзнэ гэж үргэлж санагддаг; иймээс хүмүүс бүгд өөрсдийгөө хүчлэн үргэлжлүүлэн амьдардаг. Тэд аль эртнээс зүрх сэтгэлдээ ямар ч хүчгүй болсон; тэгээд өөрсдийн үл үзэгдэх найдварыг сүнслэг багана болгон ашигладаг, тиймээс хүмүүс шиг дүр эсгэхийн тулд толгойгоо түшин өргөж, газар дээрх өдөр хоногоо аргацаан өнгөрүүлдэг. Бүх хүн, биеллээ олсон диаволын хөвгүүд шиг байдаг. Ийм учраас Бурхан: “Эмх замбараагүй байдалд нэрвэгдэн тэсвэрлэхийн аргагүй өрөвдөлтэй харагдах газар

дэлхийг сайтар ажвал дааж давшгүй уй гуниг төрдөг” хэмээн хэлсэн юм. Ийм нөхцөл байдал бий болсноос үүдэн Бурхан бүхий л орчлон ертөнц даяар “Сүнснийхээ үрийг цацаж” эхэлсэн бөгөөд авралын ажлаа бүхий л газар дээр гүйцэтгэж эхэлсэн. Энэхүү ажил урагшилсны улмаас Бурхан бүх төрлийн гай гамшгийг буулгаж, улмаар хатуу цэвдэг зүрх сэтгэлтэй хүмүүсийг аварч эхэлсэн юм. Бурханы ажлын үе шатанд аврал нь мөн л янз бүрийн гамшгийн хэлбэртэй байдаг бөгөөд үйл нь ирсэн хүмүүсээс нэг нь ч зугтаж чадахгүй. Зөвхөн эцэст нь л “гуравдагч тэнгэр мэт амгалан байдаг: Тэнд том, жижиг амьтад хэзээ ч ‘хэл ам хийлгүй’ эв эетэй зэрэгцэн оршдог” нөхцөл байдалд хүрэх боломжтой. Бурханы ажлын нэг тал нь бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, Түүний үгээр дамжуулан сонгогдсон хүмүүсийг олж авах явдал; нөгөө тал нь янз бүрийн гамшгаар дамжуулан бүх тэрслүү хөвгүүдийг байлдан дагуулах явдал юм. Энэ нь Бурханы өргөн цар хүрээтэй ажлын нэг хэсэг билээ. Ийм маягаар л Бурханы хүсдэг газар дээрх хаанчлал бүрэн хэрэгжих бөгөөд энэ нь шижир алт мэт Бурханы ажлын нэг хэсэг юм.

Тэнгэрийн хөгжил хөдөлгөөнийг ухаарахыг Бурхан хүмүүсээс байнга шаарддаг. Тэд үүнийг үнэхээр биелүүлж чадах уу? Үнэн хэрэгтээ, Сатаны 5,900 гаруй жил завхруулсан хүмүүсийн одоогийн бодит байдалд үндэслэвэл тэднийг Петртэй харьцуулж болохгүй; тийм болохоор тэд үүнийг биелүүлж ердөө чадахгүй. Энэ нь Бурханы ажлын арга барилуудын нэг юм. Тэр хүмүүсийг идэвхгүйгээр хүлээлгэхгүй; харин тэднээр идэвхтэйгээр эрж хайлгуулна. Ийм маягаар л Бурхан хүмүүс дээр ажиллах боломжтой болно. Үүнийг дахиад жаахан тайлбарласан нь дээр байх; эс бөгөөс хүмүүс ердөө өнгөц ойлголттой болох болно. Бурхан хүн төрөлхтнийг бүтээж, сүнс өгснийхөө дараа, хэрвээ Бурханыг дуудан хашхирахгүй бол тэд Түүний Сүнстэй холбогдож чадахгүй, тиймээс тэнгэрийн “хиймэл дагуулын телевизийн” дохиог газар дээр хүлээн авах боломжгүй гэж зааварласан. Бурхан хүмүүсийн сүнсэнд байхаа больж, бусад зүйлд зориулсан хоосон суудал үлдэх үед Сатан тийш орох боломжийг шүүрэн авдаг. Хүмүүс зүрх сэтгэлээрээ Бурхантай холбогдох үед Сатан даруй тэвдэн сандарч, зугтахаар яаравчилдаг. Хүн төрөлхтний хашхираанаар дамжуулан Бурхан хэрэгтэй зүйлийг нь өгдөг боловч эхэндээ тэдний дотор “оршин суудаггүй”. Тэдний хашхираанаас болж Тэр зүгээр л тэдэнд байнгын тусламж үзүүлдэг бөгөөд тэрхүү дотоод хүч чадлаас хүмүүс зориг зүрх олж авдаг, ингэснээр Сатан хүссэнээрээ “тоглохын” тулд ирж зүрхэлдэггүй. Иймээс, хэрвээ хүмүүс байнга Бурханы Сүнстэй холбогдох юм бол Сатан үймээн учруулахаар ирж зүрхэлдэггүй. Сатаны үймээнгүйгээр бүх хүний амьдрал хэвийн байж, Бурхан тэдний дотор саадгүй ажиллах боломжтой болдог. Ийнхүү Бурханы хийхийг хүсдэг зүйл хүмүүсээр дамжин биелж болно. Яагаад Бурхан хүмүүсээс итгэлээ нэмэгдүүлэхийг үргэлж шаардаж, “Би газар дээрх хүний биеийн хэмжээнд тохируулан зохих ёсны шаардлага тавьдаг. Би хэнийг ч хүнд байдалд оруулж байсан удаагүй, мөн Миний таалалд нийцэхийн тулд ‘цусаа шавх’ гэж хэнээс ч,

хэзээ ч шаардаж байгаагүй” хэмээн хэлснийг үүнээс мэдэж болно. Ихэнх хүн Бурханы шаардлагаас болж гайхширдаг. Тэгээд, хүмүүст тэрхүү эрхтэн байдаггүй, Сатан тэднийг эргэлт буцалтгүйгээр завхруулсан атал Бурхан яагаад тэдэнд шаардлага тавьсаар байдаг юм бэ? хэмээн гайхширдаг. Энэ нь, Бурхан хүмүүсийг хэцүү байр сууринд тавьж байгаа хэрэг биш үү? Хүмүүсийн буурьтай царайг хараад, дараа нь тэдний эвгүй төрхийг хараад чи инээхгүй байж чадахгүй. Хүмүүсийн янз бүрийн үзэшгүй муухай байдал хамгийн инээдтэй: Заримдаа тэд тоглох дуртай хүүхэд шиг байдаг, хааяа “ээж” болж тоглож байгаа бяцхан охин шиг байдаг. Заримдаа хулгана идэж буй нохой мэт байдаг. Тэдний энэ бүх үзэшгүй муухай байдлыг хараад хүн инээх үү, уйлах уу гэдгээ мэддэггүй бөгөөд ихэвчлэн, хүмүүс Бурханы хүслийг хэдий чинээ бага ухаарна, төдий чинээ асуудалд орж болзошгүй байдаг. Ийм учраас “Би ердөө бүх бүтээлийг чимээгүй байлгадаг Бурхан юм гэж үү?” хэмээх Бурханы үгээс хүмүүс хэр тэнэг болохыг харж болох ба нэг ч хүн Бурханы хүслийг ойлгодоггүй гэдгийг ч бас энэ нь харуулдаг. Бурхан Өөрийн хүсэл юу болохыг хэлсэн ч гэсэн тэд үүнийг анхаарч чаддаггүй. Тэд хүний хүслийн дагуу л Бурханы ажлыг хийдэг. Тийм болохоор тэд яаж Түүний хүслийг ухаарч чадах юм бэ? “Би газар дэлхийгээр алхан, анхилуун үнэрээ хаа сайгүй ханхлуулж, Өөрийн дүрийг газар сайгүй үлдээдэг. Миний дуу хоолой энд тэндгүй цуурайтдаг. Газар газрын хүмүүс өчигдрийн сайхан зураглалыг санан мөрөөсдөг, учир нь бүх хүн өнгөрснийг санаж байна…” Энэ нь хаанчлал бүрэлдэх нөхцөл байдал байх болно. Үнэндээ хэд хэдэн газарт Бурхан хаанчлалын хэрэгжилтийн үзэсгэлэнтэй сайхан байдлыг аль хэдийн зөгнөсөн ба энэ бүхэн нь нийлээд хаанчлалын бүрэн гүйцэд дүр зургийг бүрдүүлдэг. Гэвч хүмүүс үүнд ямар ч анхаарал хандуулдаггүй; тэд үүнийг зүгээр л хүүхэлдэйн кино шиг үздэг.

Сатаны завхралын мянганаас болоод хүмүүс үргэлж харанхуйд амьдарсан тул харанхуйгаас болж бачимдан зовдоггүй, гэрлийг ч хүсэн эрмэлздэггүй. Тиймээс энэ нь дараах байдалд хүргэсэн ба өнөөдөр гэрэл хүрэлцэн ирэхэд “тэд бүгд ирсэнд минь дургүйцэж, Намайг тэнгэр дэх дайсан нь мэт үзэн, айсуй гэрлийг үлдэн хөдөг. Хүн Надтай болгоомжилсон харцаар мэндчилдэг.” Хэдийгээр ихэнх хүн Бурханыг чин сэтгэлээсээ хайрлахаар хичээдэг боловч Тэр үүнд сэтгэл ханадаггүй ба хүн төрөлхтнийг мөн л ялладаг. Энэ нь хүмүүсийн хувьд учрыг нь олоход бэрх байдаг. Хүмүүс харанхуйд амьдардаг учраас гэрэлгүй байхад хийдэгтэйгээ адилаар Бурханд үйлчилсээр байдаг. Өөрөөр хэлбэл, бүх хүн өөрсдийн үзлийг ашиглан Бурханд үйлчилдэг, мөн Бурханыг ирэх үед тэдний нөхцөл байдал ийм байдаг бөгөөд тэд шинэ гэрлийг хүлээн зөвшөөрснөөр Түүнд үйлчилж чаддаггүй; харин ч туулсан бүх туршлагаараа Түүнд үйлчилдэг. Хүн төрөлхтний “үнэнч занг” Бурхан таашаадаггүй тул харанхуйд байгаа хүмүүс гэрлийг магтаж чаддаггүй. Ийм учраас Бурхан дээрх үгийг хэлсэн; энэ нь бодит байдалтай огтхон ч харшилдаггүй ба Бурхан хүн төрөлхтөнд зохисгүй хандаж байгаа юм биш, тэднийг хилсдүүлж байгаа ч юм биш. Дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш ганц ч хүн Бурханы халуун дулааныг

үнэхээр амсаагүй; хүмүүс бүгд Бурханд сонор сэрэмжтэй хандан, өөрсдийг нь цохиж, устгах вий хэмээн гүнээ айж ирсэн. Иймээс энэ 6,000 жилийн туршид Бурхан хүмүүсийн чин сэтгэлийн хариуд халуун дулааныг үргэлж ашиглан, тэднийг цаг ямагт тэвчээртэйгээр залж чиглүүлсээр байсан юм. Яагаад гэвэл, хүмүүс маш сул дорой, Бурханы хүслийг бүрэн мэдэж чаддаггүй, Түүнийг үнэн сэтгэлээсээ хайрлаж чаддаггүй, учир нь тэд өөрийн эрхгүй Сатаны арга зальд автдаг. Гэсэн ч Бурхан тэвчээртэй хэвээр байдаг бөгөөд маш тэвчээртэй байсныхаа дараа нэг л өдөр—өөрөөр хэлбэл, дэлхий ертөнцийг шинэчлэх үедээ—хүмүүсийг ээж шиг нь харж хандахаа болино. Оронд нь Тэрээр хүмүүст тохирох цээрлүүлэлтийг нь өгнө. Ийм учраас үүний дараа: “Далайн мандал дээр хүүр цогцос хөвнө”, харин “усгүй газруудад инээд хөөр, дуу хөгжим цалгин, Миний өгсөн амлалтыг бусад хүн эдэлсээр байна.” Энэ бол шийтгүүлсэн болон шагнуулсан хүмүүсийн хүрэх газрын хоорондох харьцуулалт юм. “Далайн мандал” гэдэг нь Бурханы хэлсэн, хүн төрөлхтнийг гэсгээх ёроолгүй ангалыг хэлж байна. Энэ нь Сатаны хүрэх газар бөгөөд Өөрийг нь эсэргүүцдэг бүх хүнд зориулан Бурханы бэлтгэсэн “амрах газар” юм. Бурхан хүн төрөлхтний жинхэнэ хайрыг үргэлж хүссэн атал хүмүүс үүнийг мэддэггүй, мэдэрдэггүй ба өөрсдийн ажлыг хийсээр байдаг. Үүнээс болоод Өөрийнхөө бүх үгэнд Бурхан хүмүүсээс үргэлж юм шаардаж, тэдний дутагдлыг болон хэрэгжүүлэлтийн замыг заан харуулсан болохоор тэд эдгээр үгийн дагуу хэрэгжүүлж болох юм. Бурхан хүмүүст хандах хандлагаа ийнхүү харуулсан: “Гэхдээ Би тоглоом шиг үзэн тоглох гэж ганц ч хүний амийг хээв нэг авсан удаагүй. Би хүний гаргасан хүчин чармайлтыг ажиглаж, төлсөн төлөөсийг нь ойлгодог. Өмнө минь зогсоо хүнийг Би гэнэдүүлэн гэсгээхийг хүсдэггүй, мөн түүнд таагүй зүйл өгөхийг ч хүсдэггүй. Харин ч энэ бүх хугацаанд Би гагцхүү хүнийг хангаж, хүнд өгсөн.” Хүмүүс Бурханы эдгээр үгийг унших үедээ Түүний халуун дулаан байдлыг нэн даруй мэдэрдэг: Үнэндээ өмнө нь би Бурханы төлөө төлөөс төлсөн боловч бас Түүнд хааш яаш хандаж, заримдаа Түүнд гомдоллож байсан. Бурхан намайг үгээрээ үргэлж залж чиглүүлсэн ба миний аминд маш их анхаарал хандуулдаг, гэтэл заримдаа би үүгээр тоглоом мэт тоглодог. Би үнэхээр ингэх ёсгүй. Бурхан намайг маш их хайрладаг, тэгвэл би яагаад хангалттай их хичээж чаддаггүй юм бэ? Ийм бодол төрөх үед хүмүүс үнэхээр өөрсдийгөө алгадахыг хүсдэг, эсвэл зарим хүн хамраа сартлзуулж, чангаар хашхиран уйлдаг. Бурхан тэдний бодлыг ойлгож, үүнд нийцүүлэн ярьдаг бөгөөд хатуу ч биш, зөөлөн ч биш энэ хэдэн үг нь Бурханыг гэх хүмүүсийн хайрыг төрүүлдэг. Эцэст нь Бурхан, газар дээр хаанчлал байгуулагдах үеийн Өөрийн ажил дахь өөрчлөлтийг зөгнөсөн: Бурханыг газар дээр байх үед хүмүүс гай гамшиг, зовлонгоос ангид байж, нигүүлсэлд умбаж чадна; гэвч Тэр агуу өдрийн шүүлтийг эхлэх үе нь Тэр бүх хүний дунд харагдах үе байх бөгөөд газар дээрх Түүний бүх ажил гүйцэлдэнэ. Тэр үед, цаг нь ирсэн байх учраас “Шударга бус хүн, шударга бусаараа байг: ариун нэгэн нь ариунаараа байг” хэмээн Библид бичигдсэнтэй яг адилхан байх болно. Зөв шударга бус хүмүүс гэсгээлтэд орж, ариун хүмүүс сэнтийн өмнө очно. Ганц ч хүнийг,

бүр хаанчлалын хөвгүүд, ардуудыг хүртэл Бурхан өөгшүүлэхгүй. Энэ нь бүгд Бурханы зөвт байдал бөгөөд бүгд Түүний зан чанарын илчлэл юм. Тэрээр хүний сул талыг хоёр дахь удаагаа өрөвдөн энэрэхгүй.

18-Р БҮЛЭГ

Бурханы бүх үг зан чанарынх нь нэг хэсгийг агуулдаг. Бурханы зан чанарыг үгээр бүрэн илэрхийлж болохгүй тул Бурхан яг хэчнээн баялаг болохыг харуулахад энэ нь хангалттай. Эцсийн эцэст хүмүүсийн харж, хүрч чаддаг зүйл чадвартай нь адил хязгаарлагдмал байдаг. Бурханы үг тодорхой байдаг хэдий ч хүмүүс бүрэн ойлгож чаддаггүй. Жишээлбэл, эдгээр үгийг аваад үз: “Аянгын гялбаанд амьтан бүр үнэн төрхөө харуулдаг. Тиймээс Миний гэрлээр гэрэлтүүлэгдээд хүн ч бас нэгэнтээ эзэмшиж байсан анхны ариун байдлаа сэргээсэн. Өө, завхарсан хуучин дэлхий ертөнц! Эцэстээ бохир ус руу нуран унаж, газрын гадаргаас доош живж, лаг шавар болон уусжээ!” Бурханы бүх үг Түүний оршихуйг агуулдаг, эдгээр үгийг бүх хүн мэддэг хэдий ч утга учрыг нь хэн ч, хэзээ ч мэдээгүй. Бурханы нүдээр бол Өөрийг нь эсэргүүцдэг бүх хүн Бурханы дайсан юм, өөрөөр хэлбэл, ёрын муу сүнснүүдэд харьяалагддаг хүмүүс бол адгууснууд мөн. Чуулганы жинхэнэ байр байдлыг үүнээс ажиглаж болно. Бүх хүнийг Бурханы үг гэрэлтүүлдэг бөгөөд хүмүүс бусдаас сургаал сонсож, цээрлүүлэлт амсаж, шууд халагдалгүй, аливааг хийх хүний бусад арга замд өртөлгүй, бусад хүнээр аливааг хэлүүлэлгүй энэ гэрэлд өөрсдийгөө шинждэг. Өөрсдийнх нь дотор үнэндээ хэр их өвчин эмгэг байгааг тэд “нарийвчилсан өнцгөөс” маш тодорхой олж хардаг. Бурханы үг төрөл бүрийн сүнсийг анхдагч хэлбэрээр нь ангилж, илчилдэг; тэнгэрэлчүүдийн сүнстэй хүмүүс илүү их гэрэлтүүлэгдэн, гэгээрдэг тул Бурханы үгэнд: “Нэгэнтээ эзэмшиж байсан анхны ариун байдлаа сэргээсэн” хэмээсэн байдаг. Эдгээр үг нь Бурханы хүрдэг эцсийн үр дүнд үндэслэдэг. Одоохондоо мэдээж энэ үр дүнд бүрэн хүрч хараахан чадахгүй—энэ нь ердөө л Бурханы хүслийг харж болох урьдчилсан жишээ юм. Асар олон хүн Бурханы үгэн дотор нуран унаж, бүх хүнийг ариусгах алгуур үйл явцад ялагдана гэдгийг эдгээр үг хангалттай харуулдаг. Энд “усан дахь лаг шавар болж уусжээ” хэмээсэн байгаа нь Бурхан дэлхий ертөнцийг галаар устгахтай зөрчилддөггүй бөгөөд “аянгын гялбаан” гэдэг нь Бурханы уур хилэнг хэлдэг. Бурхан асар их уур хилэнгээ буулгасны улмаас галт уул дэлбэрэх гэх мэтийн элдэв янзын гамшгийг дэлхий ертөнц тэр аяараа туулна. Газар дэлхий дээр элдэв янзын гай гамшиг бүх хүн төрөлхтөн рүү өдөр өдрөөр ойртон айсуйг тэнгэр дээр өндөрт зогсоод харж болно. Өндрөөс доош харахад газар дэлхий дээр газар хөдлөлтийн өмнөх янз бүрийн дүр зураг харагддаг. Шингэн гал саадгүй довтолгож, хайлмал лаав чөлөөтэй урсаж, уулс нүүж, бүгдийн дээгүүр жихүүн гэрэл гялтганана. Дэлхий ертөнц тэр аяараа галд живжээ. Энэ бол Бурхан уур хилэнгээ буулгаж буй дүр зураг, Бурханы

шүүлтийн цаг юм. Мах, цустай бүхэн үүнээс зайлж үл чадна. Иймээс дэлхийг тэр аяар нь сөнөөхөд улс орнуудын хоорондох дайн, хүмүүсийн хоорондох зөрчил хэрэггүй; харин дэлхий ертөнц Бурханы гэсгээлтийн өлгийд “ухамсартайгаар баясна”. Хэн ч зугтаж үл чадна; энэ зовлон зүдүүрийг хүн бүр нэг нэгээрээ даван туулах ёстой. Дараа нь орчлон ертөнц бүхэлдээ ариун туяагаар дахин нэгэнтээ гялалзаж, бүх хүн төрөлхтөн дахин нэгэнтээ шинэ амьдрал эхлүүлнэ. Бурхан орчлон ертөнцийн дээр амарч, бүх хүн төрөлхтнийг өдөр бүр ерөөнө. Тэнгэр тэсвэрлэшгүй эзгүй хоосон байхаа больж, дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш байгаагүй амин чанар нь сэргэх агаад “зургаа дахь өдөр” ирэхэд Бурхан шинэ амьдрал эхлүүлнэ. Бурхан, хүн төрөлхтний аль аль нь амралтад орж, орчлон ертөнц булингартай, бузар заваан байхаа больж, шинэчлэгдэнэ. Иймээс Бурхан: “Газар дэлхий нам гүм, дуу чимээгүй байхаа больж, тэнгэр зэлүүд, гунигтай байхаа больсон” хэмээсэн билээ. Тэнгэрийн хаанчлалд зөвт бус байдал, хүний сэтгэл хөдлөл болон хүн төрөлхтний ямар ч завхарсан зан чанар хэзээ ч байгаагүй, учир нь тэнд Сатаны үймээн гэж үгүй. “Хүмүүс” бүгд Бурханы үгийг ойлгож чаддаг бөгөөд тэнгэр дэх амьдрал баяр хөөрөөр дүүрэн амьдрал байдаг. Тэнгэр дэх бүх хүнд Бурханы мэргэн ухаан, эрхэм чанар бий. Тэнгэр газрын ялгаанаас үүдэн тэнгэрийн иргэдийг “хүмүүс” гэдэггүй; харин Бурхан тэднийг “сүнснүүд” гэж дууддаг. Энэ хоёр үг мөн чанартаа ялгаатай—одоо “хүмүүс” гэж нэрлэгдэгсдийг Сатан завхруулсан, харин “сүнснүүд”-ийг завхруулаагүй билээ. Эцэстээ Бурхан газрын хүмүүсийг тэнгэрийн сүнснүүдийн шинжтэй оршихуй болгон өөрчлөх бөгөөд дараа нь тэд Сатаны үймээнд өртөхөө болино. Энэ бол “Миний ариун байдал орчлон ертөнц даяар түгсэн” гэх үгийн жинхэнэ утга учир юм. “Газар анхны байдлаараа тэнгэрт харьяалагддаг ба тэнгэр газартай нэгдсэн байдаг. Хүн бол тэнгэр, газрыг нэгтгэх холбоос бөгөөд хүн ариун болсны ачаар, хүн шинэчлэгдсэний ачаар тэнгэр нь газраас нуугдахаа больж, газар нь тэнгэрийн зүг анир чимээгүй байхаа больсон байна.” Тэнгэрэлчийн сүнстэй хүмүүсийн тухайд ингэж хэлдэг бөгөөд энэ үед “тэнгэрэлч нар” махан биеэс болоод тэнгэрийн дээр, доор хоёр хэсэг хуваагдахаа больж, дахин амар тайвнаар зэрэгцэн оршиж, анхдагч байдлаа эргүүлэн олж авч чадна. Газар дээрх “тэнгэрэлч нар” тэнгэр дэх тэнгэрэлч нартай харилцаж чадах ба газар дээрх хүмүүс тэнгэрийн нууцыг мэдэж, тэнгэр дэх тэнгэрэлч нар хүний ертөнцийн нууцыг мэднэ. Тэнгэр газар үй зайгүй болж, нэгдэнэ. Хаанчлал биеллээ олох ийм үзэсгэлэнтэй сайхан байдаг. Бурхан үүнийг гүйцэлдүүлэх бөгөөд энэ нь бүх хүн болон сүнсний хүсэн хүлээдэг зүйл юм. Харин шашны ертөнцийнхөн энэ талаар юу ч мэддэггүй. Тэд зүгээр л Аврагч Есүс цагаан үүлэн дээр ирж, өөрсдийнх нь сүнсийг авч яваад, газар дэлхий даяар “хог” тараан хаяхыг (энд “хог” гэдгээр цогцсыг хэлжээ) хүлээж байна. Энэ нь бүх хүнд байдаг үзэл биш гэж үү? Иймээс Бурхан: “Өө, шашны ертөнц! Газар дээрх Миний эрх мэдлээс болж устахгүй байж яаж чадах билээ?” гэж хэлсэн юм. Бурхан газар дэлхий дээрх хүмүүсийг бүрэн төгс болгосноос үүдэн шашны ертөнц орвонгоороо эргэнэ. Энэ нь Бурханы хэлсэн “эрх

мэдэл” гэдгийн жинхэнэ утга юм. Бурхан: “Миний өдөр Миний нэрийг гутаан доромжлох хэн байна вэ? Бүх хүн хүндэтгэлтэй харцаар Намайг харж, зүрх сэтгэлдээ Намайг дуудаж нууцхан хашхирдаг” хэмээсэн байдаг. Шашны ертөнцийн сүйрлийн үр дагаврын талаар Бурхан ингэж хэлсэн юм. Тэд Бурханы үгээс үүдэн Бурханы сэнтийн өмнө бүхэлдээ захирагдах бөгөөд цагаан үүл бууж ирэхийг хүлээх юм уу тэнгэр өөд харахаа болиод, оронд нь Бурханы сэнтийн өмнө байлдан дагуулагдана. Иймээс “зүрх сэтгэлдээ Намайг дуудаж нууцхан хашхирдаг” гэх үг нь Бурханы бүхэлд нь байлдан дагуулах шашны ертөнцийн төгсгөл байх болно. Бурханы төгс хүчин гэдэг нь энэ—хүн төрөлхтний дундаас хамгийн тэрслүү нь болох шашны бүх хүнийг цохин унагааж, ингэснээр тэд дахин үзэлтэйгээ зууралдаж, Бурханыг танин мэдэхээ болино.

Бурханы үгэнд хаанчлалын үзэсгэлэнтэй сайхан байдлыг удаа дараа зөгнөж, янз бүрийн талыг нь хэлж, өөр өөр өнцгөөс дүрсэлсэн ч хүмүүсийн хүлээн авах чадвар хэтэрхий дулимаг тул эдгээр нь Хаанчлалын эрин үеийн нөхцөл байдал болгоныг бүрэн илэрхийлж мөн л чаддаггүй. Бурхан айлдварынхаа бүх үгийг хэлсэн ч хүмүүс тэдгээрийн доторхыг флюрографийн аппарат, рентгенээр хараагүй тул тодорхой мэдэж, ойлгодоггүй, тэр ч бүү хэл сандарч будилдаг. Энэ бол махан биеийн хамгийн том дутагдал юм. Хүмүүс хэдийгээр зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлахыг хүсдэг ч Сатаны үймээнээс болж Бурханыг эсэргүүцдэг, иймээс Бурхан тэднийг сэргээхийн тулд хөшүүн, мангуу зүрх сэтгэлд нь удаа дараа хүрсэн билээ. Бурхан гагцхүү Сатаны муу муухайг илчилдэг тул үг нь хатуу байх тусмаа Сатаныг улам бүр шившиглэж, хүмүүсийн зүрх сэтгэлийн хүлээсийг багасгаж, хүмүүсийн хайрыг илүү их өдөөж чаддаг. Бурхан ингэж ажилладаг. Сатан илчлэгдэж, нэвт шувт харагдсан тул хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдэж зүрхлэхээ байж, улмаар тэнгэрэлч нар дарлагдахаа больдог. Ийм маягаар тэд Бурханыг бүхий л зүрх сэтгэл, оюун ухаанаараа хайрладаг. Тэдний жинхэнэ төрх буюу тэнгэрэлч нар Бурханд харьяалагдаж, Бурханыг хайрладаг нь тэр үед л тодорхой харагддаг. Ийм замаар л Бурханы хүсэл биелж чадна. “Бүх хүний зүрх сэтгэл дотор Надад зориулсан орон зай байдаг. Би хүмүүсийн дунд зэвүүцэл юм уу гололттой дахин тулгарахгүй, учир нь Миний агуу ажил аль хэдийн гүйцэлдсэн бөгөөд дахин саад тохиолдохгүй.” Дээр дүрсэлсэн зүйлийн утга учир энэ юм. Сатан амар заяа үзүүлдэггүйгээс үүдэн хүмүүст Бурханыг хайрлах цаг олддоггүй бөгөөд ертөнцийн юмстай үргэлж орооцолдон, Сатаны төөрөгдөлд автсан тэд будилуу байдлаар үйлддэг. Иймээс Бурхан, хүн төрөлхтнийг “амьдралын маш олон бэрхшээлийг, дэлхий ертөнцийн шударга бус үйл явдлыг, дэлхий ертөнцийн маш олон аз, эзийг туулаад одоо Миний гэрэлд амьдардаг. Өчигдрийн шударга бус явдлын төлөө үйлдаггүй хэн байх билээ?” гэж хэлсэн билээ. Хүмүүс энэ үгийг сонсоод Бурхан өөрсөдтэй нь хамт шаналж, цугтаа эмгэнэн гашуудаж, тухайн үед гомдлыг нь хуваалцаж байх шиг санагддаг. Тэд хүний ертөнцийн шаналлыг гэнэт мэдэрч, “Яг үнэн. Би энэ ертөнцөд хэзээ ч, юуг ч таашаан эдэлж байгаагүй. Эхийн хэвлийгээс

төрснөөсөө хойш өнөөг хүртэл би хүний амьдралыг туулаад юу ч олж аваагүй, харин маш их зовсон. Энэ бүгд хов хоосон! Бас одоо намайг Сатан маш их завхруулсан! Өө! Бурханы аврал байгаагүй бол үхэх цаг минь болоход би бүхий л амьдралаа хий дэмий өнгөрүүлсэн байх бус уу? Хүний амьдралд ямар нэг утга учир бий юу? Нарны доорх бүх зүйл хий хоосон гэж Бурхан хэлсэнд гайхах зүйл алга. Өнөөдөр Бурхан намайг гэгээрүүлээгүй бол би харанхуйд л байх байсан. Яасан хөөрхийлөлтэй юм бэ!" гэж боддог. Тэр үед зүрх сэтгэлд нь болгоомжлол төрж, "Хэрвээ би Бурханы амлалтыг олж авч чадахгүй бол амьдралыг үргэлжлүүлэн туулж яаж чадах юм бэ?" гэдэг. Энэ үгийг уншдаг хүн бүр залбирах зууraa нулимс унагана. Хүний сэтгэл санаа ийм л байдаг. Сэтгэц нь хэвийн бус биш л бол хүн үүнийг уншаад ямар ч хариу үйлдэл үзүүлэхгүй байх боломжгүй. Бурхан өдөр бүр янз бүрийн хүмүүсийн байр байдлыг илчилдэг. Заримдаа Бурхан тэдний өмнөөс гомдол тоочдог. Заримдаа Тэрээр хүмүүст тодорхой нэг орчныг ялж, амжилттай даван туулахад тусалдаг. Заримдаа Бурхан хүмүүст "өөрчлөлтийг нь" хэлж өгдөг. Эс бөгөөс хүмүүс амь нь хэр их өссөнийг мэдэхгүй байх байлаа. Заримдаа Бурхан бодит байдал дахь хүмүүсийн туршлагыг хэлж өгдөг бөгөөд зарим үед дутагдал, өө сэвийг нь хэлж өгдөг. Хаяа Бурхан тэдэнд шинэ шаардлага тавьж, заримдаа Бурханыг ойлгодог түвшнийг нь хэлж өгдөг. Гэхдээ Бурхан бас: "Би маш олон хүний чин сэтгэлээсээ хэлсэн үгийг сонсож, зовлон зүдүүр дундах шаналгаат туршлагынхаа талаар маш олон хүний ярихыг сонссон; хүнд бэрх нөхцөлд үнэнч байдлаа Надад өргөн барьдаг маш олон хүнийг Би харсан ба бартаат замаар алхангаа гарах гарц хайж байгаа маш олон хүнийг ажигласан" гэж хэлсэн. Энэ бол эерэг дүрийн тодорхойлолт юм. "Хүний түүхийн олон ангит киноны" анги болгонд эерэг дүр төдийгүй сөрөг дүр ч бас байсан юм. Тиймээс Бурхан эдгээр сөрөг дүрийн муу муухайг үргэлжлүүлэн илчилдэг. Иймээс, "урвагчтай" харьцуулснаар л "шулуун шударга хүмүүсийн" нугаршгүй үнэнч байдал, эрэмгий зориг ил болдог. Бүх хүний амьдралд сөрөг хүчин зүйл байхын зэрэгцээ бүгдэд нь бас эерэг хүчин зүйл бий. Урвагчид толгой гудайлган, нүглээ хүлээг, шулуун шударга хүмүүс урам аван цаашид ч үнэнч байг гэсэндээ Бурхан бүх хүний тухай үнэнийг илчлэхийн тулд энэ хоёрын аль алийг ашигладаг. Бурханы үгийн далд утга санаа маш гүн гүнзгий. Заримдаа хүмүүс тэдгээрийг уншаад элгээ хөштөл инээдэг бол бусад үед чимээгүйхэн толгой гудайлгадаг. Зарим үед тэд дурсан санагалзаж, заримдаа гашуунаар уйлж, нүглээ хүлээн, заримдаа тэмтчиж, заримдаа эрж хайдаг. Ерөнхийдөө Бурхан үг хэлдэг өөр өөр орчин нөхцөлөөс үүдэн хүмүүсийн хариу үйлдэл өөрчлөгддөг. Бурханы үгийг уншиж буй хүнийг заримдаа хөндлөнгийн хүмүүс сэтгэцийн өвчтэй гэж эндүүрч ч магадгүй. "Иймээс, газар дээрх хэрүүл маргаан үгүй болж, Миний үгийг дагаад орчин үеийн элдэв янзын 'зэвсэг' ч бас хураагддаг" гэх үгийг аваад үз. "Зэвсэг" гэх үг дангаараа л гэхэд бүтэн өдөржин инээд хүргэж чадах бөгөөд "зэвсэг" гэх үгийг санамсаргүй санах бүрдээ хүн чангаар инээнэ. Тэгнэ биз дээ? Чи үүнд инээхгүй байж яаж чадах юм бэ?

Чи инээх үедээ Бурхан хүн төрөлхтнөөс юу шаарддагийг ухаарахаа бүү март, чуулганы үнэн байдлыг харахаа бүү умарт: “Бүх хүн хэвийн байдалдаа эргэн орж, шинэ амьдрал эхлүүлсэн. Шинэ орчинд амьдарч байхдаа үлэмж олон хүн эргэн тойрноо хараад цоо шинэ ертөнцөд ирсэн мэт санагддаг, тийм учраас тэд одоогийн орчиндоо нэн даруй дасан зохицоод, зөв замд даруй орж чаддаггүй.” Чуулганы үнэн байдал одоогоор ийм байна. Бүх хүнийг даруйхан зөв замд оруулах гэж хэтэрхий их бүү санаа зов. Ариун Сүнсний ажил тодорхой цэгт ахин дэвшсэн цагт хүмүүс бүгд өөрсдийн мэдэлгүй үүнд орно. Бурханы үгийн мөн чанарыг ухаарах үедээ чи Бурханы Сүнс ямархуу хэмжээнд хүртэл ажилласныг мэднэ. Бурханы хүсэл бол: “Би хүн бүрийг зөв замд оруулахын тулд зөв шударга бус байдлаас нь хамаарч, тохиромжтой ‘боловсрол’ олгодог.” Энэ бол Бурханы үг хэлж, ажиллах арга зам төдийгүй хүн төрөлхтний хэрэгжүүлэх тодорхой зам юм. Үүний дараа Бурхан хүн төрөлхтний өөр нэг байдлыг хүмүүст хэлж өгсөн: “Хэрвээ хүмүүс Миний дотор байгаа аз жаргалыг эдлэх хүсэлгүй бол Би тэдний хүслээр болгохоос өөр юм хийж чадахгүй бөгөөд тэднийг ёроолгүй гүн нүх рүү илгээнэ.” Бурхан нарийн нягт хэлж, хүмүүст гомдоллох өчүүхэн ч боломж үлдээгээгүй. Яг энэ л Бурхан, хүн хоёрын ялгаа юм. Бурхан хүнд үргэлж ил тод, чөлөөтэй байдлаар үг хэлж байгаа. Бурханы хэлдэг бүх зүйлээс чин үнэнч зүрх сэтгэлийг нь харж болох бөгөөд үүнээс үүдэн хүмүүс зүрх сэтгэлээ Бурханыхтай харьцуулж, солонгын аль өнгөнд хамаардгаа харуулахын тулд зүрх сэтгэлээ Бурханд уудлахад хүрдэг. Бурхан ямар ч хүний итгэл, хайрыг хэзээ ч шагшин магтаагүй, харин үргэлж хүмүүст шаардлага тавьж, муу муухай талыг нь ил болгож ирсэн билээ. Энэ нь хүмүүсийн “биеийн хэмжээ” ямар өчүүхнийг, “бие хаа” нь хэчнээн дутуу дулимгийг харуулдаг. Тэдгээр дутагдлыг залруулахын тулд тэдэнд илүү их “дасгал” хэрэгтэй тул Бурхан цаг ямагт хүмүүст “уураа гаргадаг”. Бурхан хүн төрөлхтний үнэн төрхийг илчилсэн нэг өдөр хүмүүс бүрэн төгс болгуулж, Бурханы санаа амарна. Хүмүүс Бурханыг аргалахаа больж, Бурхан хүмүүсийг “сурган хүмүүжүүлэхээ” болино. Тэр үеэс хойш хүмүүс “бие даан амьдарч” чадах боловч одоо цаг нь болоогүй байна. Хүмүүсийн дотор “хуурамч” гэж болохоор юм нэлээд байгаа бөгөөд дахиад хэдэн удаагийн үзлэг, “татвараа” зохих ёсоор нь төлж болох дахиад хэд хэдэн “шалган нэвтрүүлэх цэг” зохицуулж тавих хэрэгтэй байна. Хэрвээ хуурамч бараа байсаар байвал тэдгээрийг заруулахгүйн тулд хураан аваад, хууль бусаар нэвтрүүлсэн энэ багц барааг устгана. Ингэж хийх нь бүр сайн биш үү?

19-Р БҮЛЭГ

Хүмүүсийн төсөөллөөр Бурхан маш сүрлэг агаад ойлгохын аргагүй санагддаг. Бурхан хүмүүсийн дунд оршин суудаггүй мэт, Тэр маш сүрлэг болохоор хүмүүсийг басамжилдаг мэт байдаг. Гэвч Бурхан хүмүүсийн үзлийг эвдэж, бүгдийг нь таягдан

хаяж, “булшинд” булаад үнсэн товрог болгодог. Хүний үзэлд хандах Бурханы хандлага үхэгсдэд хандах хандлагатай нь адилхан, тэднийг дур зоргоороо тодорхойлж байдаг. “Үзэл” ямар ч хариу үйлдэл үзүүлэхгүй байгаа мэт байдаг; тиймээс Бурхан дэлхий ертөнц бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл энэ ажлыг хийсээр байгаа бөгөөд хэзээ ч зогсоогүй. Махан биеэс болж хүмүүс Сатанаар завхруулагдсан бөгөөд газар дээрх Сатаны үйлдлүүдээс болоод хүмүүс туршлагынхаа явцад төрөл бүрийн үзлийг бий болгодог. Үүнийг “ердийн үүсэл” гэж нэрлэдэг. Энэ нь газар дээрх Бурханы ажлын сүүлчийн үе шат тул Бурханы ажлын арга барил оргилдоо хүрсэн ба Тэрээр хүмүүсийг сургахаа эрчимжүүлж байгаа, ингэснээр тэд Түүний сүүлчийн ажлаар бүрэн төгс болгуулж, эцэстээ Бурханы хүслийг хангаж чадна. Өмнө нь хүмүүсийн дунд Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт л байсан боловч Бурханы Өөрийнх нь хэлсэн ямар ч үг байхгүй байв. Бурхан Өөрийн дуу хоолойгоор ярих үед хүн бүхэн гайхширсан бөгөөд өнөөдрийн үг бүр ч адармаатай байдаг. Тэдгээрийн утга учрыг ухан ойлгоход бүр ч хэцүү бөгөөд Түүний үгийн тавин хувь нь хашилтанд байдаг учраас хүмүүсийн нүд эрээлжилж байх шиг санагддаг. “Намайг үг хэлэх үед хүмүүс Миний дуу хоолойг анхаарлаа төвлөрүүлэн сонсдог; харин Намайг үг хэлэхээ болиход өөрсдийн ‘ажил хэргийг’ дахин эхлүүлдэг.” Энэ хэсэгт хашилтан дотор үг бий. Энд ярьсантай адилаар Бурхан хэдий чинээ хошигнон ярина, хүмүүсийн унших дурыг төдий чинээ хөдөлгөдөг. Тэгээд хүмүүс тайван байх үедээ харьцалтыг хүлээн авч чаддаг. Гэхдээ үндсэндээ энэ нь, Бурханы үгийг ойлгохгүй байх үедээ илүү олон хүн шантарч, сэтгэлээр унахаас сэргийлэхийн төлөө байдаг. Энэ бол Сатантай хийх Бурханы дайны тактик билээ. Ийм маягаар л хүмүүс Бурханы үгийг сонирхсон хэвээр байж, будилсан үедээ ч гэсэн тэдгээрт анхаарал хандуулсаар байх болно. Гэхдээ хашилтаар хүрээлэгдээгүй бүх үг нь ч гэсэн асар их увдистай байдаг тул илүү анзаарагдахуйц байдаг бөгөөд Бурханы үгийг бүр их хайрлаж, Түүний үгийн сайхан амтыг зүрх сэтгэлдээ мэдрэхэд хүмүүсийг хүргэдэг. Бурханы үг асар олон хэлбэртэйгээр ирдэг бөгөөд баялаг, олон янз байдаг тул, мөн Бурханы олон үгэн дунд нэр үг давтагддаггүй учраас Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин биш гэж хүмүүс гурав дахь мэдрэхүйгээрээ үздэг. Жишээлбэл: “Би хүмүүсээс ‘хэрэглэгч’ төдий бай гэж шаарддаггүй; харин Сатанд ялагдал учруулах ‘үйлдвэрлэгч’ бай гэж шаарддаг.” Энэ өгүүлбэрт байгаа “хэрэглэгч” болон “үйлдвэрлэгч” хэмээх үг урьд нь хэлж байсан зарим үгтэй төстэй утгатай боловч Бурхан хатуу хөшүүн биш; харин ч Тэрээр хүмүүст Өөрийн шинэлэг байдлыг мэдүүлж, улмаар Бурханы хайрыг нандигнахад тэднийг хүргэдэг. Бурханы үгэн дэх хошигнол нь хүнийг гэх Түүний шүүлт болон Түүний шаардлагыг агуулдаг. Бурханы үг бүгд зорилготой, бүгд утга учиртай байдаг тул Түүний хошигнол зүгээр л уур амьсгалыг зөөлрүүлж, эсвэл хүмүүсийг нирхийтэл инээлгэх зорилготой биш, мөн зүгээр л тэдний булчин шөрмөсийг суллах зорилготой ч биш. Харин Бурханы хошигнол нь хүмүүсийг таван мянган жилийн хүлээсээс чөлөөлж, дахин хэзээ ч хүлэгдэхгүй байлгахаар зорьдог,

ингэснээр тэд Бурханы үгийг илүү сайн хүлээн авч чаддаг. Бурханы арга барил бол эмийг шингээхэд тусалдаг ганц халбага элсэн чихэр юм; Тэрээр хүмүүст гашуун эм залгиулахаар хүчилдэггүй. Чихрэн дотор гашуун амт байдаг бөгөөд мөн гашууны дотор чихэрлэг амт байдаг.

“Зүүн зүгт бүдэгхэн сүүмэлзэх гэрэл харагдаж эхлэх үед, түүнээс болж орчлон ертөнц дээрх бүх хүн Зүүн зүг дэх гэрэлд бага зэрэг анхаарал хандуулдаг. Хүн нойронд умбахаа болиод зүүний гэрлийн эх сурвалжийг ажиглахаар явах боловч хүний хүч чадлын хязгаарын улмаас гэрэл гарч байгаа газрыг хэн ч харж чаддаггүй.” Энэ бол зөвхөн Бурханы хөвгүүд, ардуудын дунд ч биш, харин орчлон ертөнцөд хаа сайгүй тохиолдож байгаа зүйл юм. Шашны хүрээнийхэн болон үл итгэгчид бүгд ийм хариу үйлдэл үзүүлдэг. Бурханы гэрэл цацрах мөчид бүх хүний зүрх сэтгэл аажмаар өөрчлөгддөг ба өөрсдийнх нь амьдрал утга учиргүй, хүний амьдрал үнэ цэнгүй гэдгийг тэд өөрийн эрхгүй мэдэж авч эхэлдэг. Хүмүүс ирээдүйг эрэлхийлж, маргаашийг бодолцон үзэж, эсвэл маргаашийн талаар санаа зовдоггүй; харин “залуу” байгаа дээрээ илүү их идэж, уух ёстой, тэгвэл эцсийн өдөр ирэхэд энэ бүхэн үнэ цэнтэй байх болно гэсэн үзэл санаа баримталдаг. Хүмүүст дэлхий ертөнцийг захирах ямар ч хүсэл байдаггүй. Дэлхий ертөнцийг гэх хүний хайрын эрч хүчийг “диавол” бүрмөсөн хулгайлсан боловч эх үндэс нь юу болохыг хэн ч мэддэггүй. Бурханы өдөр хараахан ирээгүй учраас тэд нааш цааш гүйж, нэг нэгэндээ мэдэгдэж л чадна. Нэг л өдөр бүх ойлгошгүй нууцын хариултыг хүн бүр харах болно. Энэ нь “Хүн зүүд нойрноос сэрж, Миний өдөр өөрсөд дээр нь аажмаар ирж буйг дөнгөж л ухаарна” хэмээх Бурханы үгийн жинхэнэ утга учир юм. Тэр цаг ирэх үед Бурханд харьяалагддаг бүх хүн “Намайг газар дээр байх хугацаанд өөрсдийн хувийг Надад зориулахаар хүлээж” буй ногоон навчис шиг байх болно. Бурхан Өөрийн дуу хоолойг айлдсаны дараа Хятад дахь Бурханы ардуудын дундаас маш олон хүний хуучин гэм нь хөдөлдөг, иймээс Бурхан: “…гүйцэлдсэн баримт нэгэнтээ өөрчлөгдөшгүй болж, зөвхөн ял тулгахыг минь хүлээхээс өөр аргагүй байдаг билээ” гэдэг. Тэдний дунд таягдан хаягдах зарим хүн мөн л байх болно—бүгд өөрчлөгдөхгүй хэвээр үлдэхгүй. Харин ч хүмүүс туршилт туулсныхаа дараа л стандартад нийцэж чадах ба тэгснээр тэдэнд “чанарын гэрчилгээ” нь хэвлэгдэх болно; эс бөгөөс тэд хогийн овоон дээрх хог новш болох болно. Бурхан хүний жинхэнэ байр байдлыг үргэлж заан харуулдаг тул хүмүүс Бурханы нууцлаг байдлыг улам их мэдэрдэг. “Хэрвээ Тэр Бурхан байгаагүй бол бидний жинхэнэ байр байдлыг яаж ийм сайн мэдэж чадах юм бэ?” Гэсэн ч хүмүүсийн сул талаас үүдэн “хүмүүсийн зүрх сэтгэлд Би агуу дээд ч биш, эгэл дорд ч биш байдаг. Хүмүүсийн хувьд Миний оршдог эсэх нь ямар ч ялгаагүй.” Энэ нь чухамдаа бодит байдалд хамгийн сайн тохирох бүх хүний байр байдал биш гэж үү? Хүмүүсийн тухайд бол, тэднийг Бурханыг эрж хайх үед Тэр оршдог ба Түүнийг эрж хайгаагүй үед Тэр оршдоггүй. Өөрөөр хэлбэл, хүмүүст Бурханы тусламж хэрэгтэй үед Тэрээр хүмүүсийн зүрх сэтгэлд нэн даруй оршдог боловч тэдэнд хэрэггүй болох үед

Бурхан оршин байхаа больдог. Энэ бол хүмүүсийн зүрх сэтгэлд байдаг зүйл юм. Бодит байдал дээр, бүх “бурхангүй үзэлтнийг” оролцуулаад газар дээрх хүн бүр ингэж боддог ба Бурханы талаарх “сэтгэгдэл” нь тодорхойгүй, бүдэг бадаг байдаг.

“Тиймээс, уулс хуурай газар дээрх улс үндэстнүүдийн хооронд хил хязгаар болж, ус хуурай газруудын хооронд хүмүүсийг тусгаарлах хаалт болж, агаар нь газар дэлхий дээрх орон зайд хүнээс хүн рүү урсдаг зүйл болдог.” Энэ нь дэлхий ертөнцийг бүтээх үед Бурханы хийсэн ажил байв. Үүнийг энд дурдах нь хүмүүсийн хувьд будилмаар байдаг: Бурхан өөр ертөнцийг бүтээхийг хүссэн юм гэж үү? Ингэж хэлэх нь зүйтэй юм: Бурханыг ярих болгонд үг нь бүтээл, удирдлага, дэлхий ертөнцийн сүйрлийг агуулдаг; зүгээр л заримдаа тэдгээр нь тодорхой, заримдаа тодорхойгүй байдаг. Бурханы бүх удирдлага Түүний үгэнд биеллээ олдог; зүгээр л хүмүүс тэдгээрийг ялган салгаж чаддаггүй. Хүмүүст өгдөг Бурханы ерөөл итгэлийг нь зуу дахин өсгөдөг. Гаднаасаа Бурхан хүмүүст амлалт өгч байгаа мэт санагддаг боловч мөн чанартаа энэ нь, Өөрийн хаанчлалын ардуудад тавих Бурханы шаардлагын хэмжүүр юм. Ашиглахад тохиромжтой хүмүүс үлдэнэ, харин тохиромжгүй хүмүүс тэнгэрээс буудаг гай гамшигт залгиулна. “Тэнгэрт аянга нүргэлэн хүмүүсийг ниргэн унагана; өндөр уулс нуран унахдаа тэднийг булшилна; зэрлэг араатнууд өлссөндөө тэднийг залгина; далай тэнгис давлагаалах үедээ толгой дээгүүр нь нөмрөн авна. Хүмүүс хоорондоо хөнөөн тэмцэлдэх үедээ өөрсдөөс нь урган гардаг гамшгаас болж бүгд сүйрлээ эрнэ.” Энэ бол стандартад нийцдэггүй хүмүүст оноох “тусгай үйлчилгээ” бөгөөд дараа нь тэд Бурханы хаанчлалд аврагдахгүй. Бурхан: “Та нар Миний гэрлийн удирдамж дор харанхуйн хүчний дарлалаас гарцаагүй ангижирч, харанхуйн дунд өөрсдийг чинь замчлах гэрлийг алдахгүй нь лавтай” гэх мэтийн зүйлсийг хэдий чинээ их хэлнэ, хүмүүс өөрсдийнхөө хүндтэй байдлыг төдий чинээ их мэддэг; ийм болохоор шинэ амьдралыг эрж хайх итгэл төдий чинээ их байдаг. Хүмүүсийг Өөрөөс нь хүсэхийн хэрээр Бурхан тэднийг хангадаг. Бурхан тэднийг тодорхой түвшинд илчилмэгцээ Өөрийнхөө ярианы байдлыг өөрчилж, хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд ерөөлийн өнгө аяс ашигладаг. Ийм маягаар хүмүүст шаардлага тавих нь илүү бодитой үр ашиг өгдөг. Хүмүүс бүгд, хамтрагчидтайгаа ажил хэрэг ярих дуртай байдаг—тэд бүгд ажил хэрэгтээ мэргэжилтнүүд—үүнийг хэлснээрээ Бурхан яг энийг л тодруулсан юм. Тэгвэл “Синим” гэж юу вэ? Энд Бурхан Сатаны завхруулсан газар дээрх хаанчлалыг хэлээгүй, харин Бурханаас ирсэн бүх тэнгэрэлчийн цуглааныг хэлсэн. “Бат, тууштай” хэмээх үг нь тэнгэрэлчүүд Сатаны бүх хүчийг бут цохиж, улмаар бүхий л орчлон ертөнц даяар Синимийг байгуулна гэсэн утгатай. Иймээс Синимийн жинхэнэ утга учир нь газар дээрх бүх тэнгэрэлчийн цуглаан бөгөөд энд энэ нь газар дээрх хүмүүсийг хэлдэг. Иймээс хожим газар дээр орших хаанчлалыг “хаанчлал” биш, харин “Синим” гэж нэрлэнэ. Газар дээрх “хаанчлалд” ямар ч бодит утга учир байхгүй; энэ нь мөн чанартаа Синим юм. Иймээс үүнийг Синимийн тодорхойлолттой холбосноор л хүн “Та нар бүхий л орчлон ертөнц даяар Миний

алдрыг цацруулах нь дамжиггүй” хэмээх үгийн жинхэнэ утгыг мэдэж чадна. Энэ нь хожмын газар дээрх бүх хүний зиндааг харуулдаг. Синимийн хүмүүс бүгдээрээ, гэсгээлт туулсныхаа дараа газар дээрх бүх хүнийг захирах хаадууд байх болно. Синимийн хүмүүсийн удирдлагаас болж газар дээрх бүх зүйл хэвийн ажиллана. Энэ нь нөхцөл байдлын ноорог зураглалаас цаашгүй. Бүх хүн Бурханы хаанчлал дотор үлдэнэ, өөрөөр хэлбэл, тэд Синимд үлдэнэ. Газар дээрх хүмүүс тэнгэрэлчүүдтэй ярилцаж чадна. Иймээс тэнгэр, газар холбогдоно; өөрөөр хэлбэл, газар дээрх бүх хүн тэнгэр дэх тэнгэрэлчүүдийн адилаар Бурханд захирагдаж, Түүнийг хайрлана. Тэр үед Бурхан газар дээрх бүх хүнд ил тод харагдаж, тэдний нүдэнд Өөрийн үнэн царайг харуулах бөгөөд хэдийд ч Өөрийгөө тэдэнд харуулна.

20-Р БҮЛЭГ

Бурхан бүх хүн төрөлхтнийг бүтээсэн ба тэднийг удирдан чиглүүлсээр өнөөдрийг хүргэсэн. Тиймээс хүмүүсийн дунд тохиолдож байгаа бүхнийг Бурхан мэддэг: Тэр хүний ертөнцийн гашуун зовлонг мэддэг, хүний ертөнцийн сайн сайхныг ойлгодог, иймээс өдөр бүр Тэр бүх хүн төрөлхтний амьдралын нөхцөл байдлыг тодорхойлж, цаашлаад бүх хүн төрөлхтний сул тал болон завхралтай харьцдаг. Бүх хүн төрөлхтнийг ёроолгүй нүх рүү хаях нь, эсвэл хүн төрөлхтнийг бүхэлд нь аврах нь Бурханы хүсэл биш юм. Бурханы үйлдэлд үргэлж зарчим байдаг, гэвч Түүний хийдэг бүхний хуулийг хэн ч ухаарах чадваргүй байдаг. Хүмүүс Бурханы сүр жавхлан, уур хилэнг мэддэг болох үед Бурхан өнгө аясаа нэн даруй өршөөл, хайр болгон өөрчилдөг боловч хүмүүс Бурханы өршөөл, хайрыг мэдэж авах үед Тэр Өөрийн үгийг, амьд тахиа мэт идэхэд хэцүү болгож, өнгө аясаа дахин нэгэнтээ өөрчилдөг. Бурханы бүх үгэнд эхлэл нь хэзээ ч давтагдаж байгаагүй, мөн Түүний үгийн аль нь ч, хэзээ ч өчигдрийн айлдваруудын зарчмын дагуу хэлэгдэж байгаагүй; өнгө аяс нь ч адилхан биш, мөн агуулгад нь холбоотой зүйл юу ч байхгүй—энэ бүхэн нь хүмүүсийг улам илүү будилуулдаг. Энэ бол Бурханы мэргэн ухаан, Түүний зан чанарын илчлэл юм. Тэрээр хүмүүсийн үзлийг сарниулж, Сатаныг төөрөгдүүлж, Бурханы үйл хэргийг хордуулах боломжгүй болгохын төлөө Өөрийн ярианы өнгө болон хэв маягийг ашигладаг. Бурханы үйлдлийн гайхалтай байдал нь хүмүүсийн оюун ухаан Бурханы үгэнд алмайрч хоцроход хүргэдэг. Тэд гэрийнхээ үүдийг арай ядан олж чаддаг, хэзээ идэж, амрах ёстойгоо хүртэл мэддэггүй, тиймээс үнэхээр “Бурханы төлөө зарлагадахын тулд нойр, хоолоо умартдаг”. Гэхдээ энэ мөчид ч гэсэн Бурхан өнөөгийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун байдаггүй ба хүнээс үнэн зүрх сэтгэлээ харуулахыг шаардаж, үргэлж түүнд уурлаж байдаг. Эс бөгөөс Бурхан өчүүхэн төдий өршөөл үзүүлмэгц хүмүүс даруйхан “дуулгавартай дагаж”, цалгар назгай болдог. Энэ бол хүний дорд байдал; түүнийг аргадаж болохгүй, харин түүнийг хөдөлгөхийн тулд зодож занчиж, эсвэл чирэх ёстой. “Миний хардаг бүх хүнээс нэг

нь ч Намайг хэзээ ч өөрийн ухамсраар, шууд эрж хайгаагүй. Тэд бүгд бусдын шахалтаар, олонхыг дагаж Миний өмнө ирдэг бөгөөд тэд өөрсдийн амьдралыг баялаг болгохын тулд төлөөс төлөх юм уу цаг хугацаа зарцуулах хүсэлгүй байдаг.” Газар дээр байгаа бүхний нөхцөл байдал ийм билээ. Тиймээс элч нар, эсвэл удирдагч нарын ажилгүйгээр бүх хүн хэдийнээ тарж бутрах байсан, иймд эрин үеүдийн туршид элч нар болон эш үзүүлэгчдээр дутагдаж байгаагүй билээ.

Эдгээр айлдварт Бурхан бүх хүн төрөлхтний амьдралын нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэхэд онцгой анхаарал хандуулдаг. Дараах шиг үгс нь бүгд ийм төрлийнх юм: “Хүний амьдралд өчүүхэн төдий ч халуун дулаан байдал байдаггүй бөгөөд хүн чанарын ямар ч ул мөр, гэрэл гэгээ байдаггүй—гэсэн ч тэр үргэлж өөрийгөө өөгшүүлж, юунд ч хүрсэн юмгүй яаран тэвдэж, насан туршдаа ямар ч үнэ цэнгүй амьдардаг. Насан эцэслэх өдөр нь нүд ирмэхийн зуур ойртож, хүн гашуун үхлээр нас бардаг.” Яагаад Бурхан хүн төрөлхтний амьдралыг өнөөдрийг хүртэл залж чиглүүлж, бас хүний ертөнц дэх амьдралын хоосон байдлыг илчилдэг юм бэ? Яагаад Тэр бүх хүний насан туршийн амьдралыг “яаран ирж, яаран оддог” хэмээн тодорхойлдог юм бэ? Энэ бүгд нь Бурханы төлөвлөгөө, энэ бүгдийг Бурхан урьдаас шийддэг, тийм болохоор нөгөө талаараа бурханлаг чанар дахь амьдралаас бусдыг нь Бурхан хэрхэн жигшдэгийг энэ нь тусгадаг гэж хэлж болно. Бурхан бүх хүн төрөлхтнийг бүтээсэн хэдий ч Тэр бүх хүн төрөлхтний амьдралыг үнэндээ хэзээ ч таашаагаагүй, иймээс Тэр ердөө л, хүн төрөлхтөнд Сатаны завхрал дор орших боломж олгодог юм. Хүн төрөлхтөн энэ үйл явцыг туулсны дараа Тэр хүн төрөлхтнийг үндсээр нь устгаж, эсвэл аварна, тэгснээр хүн газар дээр хий хоосон бус амьдралд хүрэх болно. Энэ бүгд нь Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг юм. Иймээс хэн ч гэм зэмгүй үхлээр баяртайгаар үхдэггүй байхад хүргэсэн хүсэл хүний ухамсарт үргэлж байдаг боловч энэ хүсэлд хүрдэг хүмүүс нь зөвхөн эцсийн өдрүүдийн хүмүүс билээ. Өнөөдөр хүмүүс эргэлт буцалтгүй хоосон байдал дунд амьдарсаар байдаг ба тэд тэрхүү үл үзэгдэх хүслийг хүлээсээр байдаг: “Би Өөрийн гараар нүүрээ далдалж, хүмүүсийг газар доор дарахад тэдний амьсгал даруй давчдаж, бараг л амьдрах боломжгүй болдог. Өөрсдийг нь устгана хэмээн Надаас тэд бүгд айж, бүгдээрээ Намайг дуудан хашхирдаг, учир нь тэд бүгд Миний алдрыг олж авах өдрийг харахыг хүсдэг билээ.” Өнөөдрийн бүх хүний нөхцөл байдал ийм юм. Тэд бүгд “хүчилтөрөгчгүй” “хоосон орчинд” амьдардаг ба тэдний хувьд амьсгалахад хэцүү байдаг. Бурхан, бүх хүн төрөлхтний амьд гарах чадварыг дэмжихийн тулд хүний ухамсарт байгаа хүслийг ашигладаг; эс бөгөөс бүгдээрээ “лам болохын тулд гэрээ орхих” байсан, үүний үр дүнд хүн төрөлхтөн мөхөж, төгсгөлдөө очих байсан юм. Тиймээс хүнд Бурханы өгсөн амлалтын улмаас хүн өнөөдрийг хүртэл амьд үлдсэн. Энэ бол үнэн, гэхдээ хүн хэзээ ч энэ хуулийг нээж илрүүлээгүй, тиймээс тэр яагаад “үхэл өөр лүү нь хоёр дахь удаагаа ирэх вий гэдгээс ихэд айдгаа” мэддэггүй. Хүн байтлаа үргэлжлүүлэн амьдрах зориг зүрх хэнд ч байдаггүй, гэвч бас хэнд ч, хэзээ ч үхэх зориг зүрх байгаагүй, тиймээс

Бурхан, хүмүүс “гашуун үхлээр нас бардаг” гэж хэлдэг. Хүмүүсийн дундах жинхэнэ нөхцөл байдал ийм юм. Магадгүй зарим хүн хэтийн ирээдүйдээ бүтэлгүйтэлтэй тулгарч, үхлийн тухай бодсон байх, гэхдээ эдгээр бодол нь хэзээ ч биеллээ олоогүй; магадгүй зарим нь гэр бүлийн зөрчилдөөнөөс болж үхлийн тухай боддог боловч хайртай хүмүүстээ санаа зовж, өөрсдийн хүсэлд хүрч чадалгүй үлддэг байх; мөн магадгүй зарим нь гэрлэлт нь бүтэлгүйтсэнээс болж үхлийн тухай бодсон боловч үүнийг хэрэгжүүлэхийг хүсээгүй байх. Тиймээс хүмүүс, зүрх сэтгэлдээ гомдолтойгоор, эсвэл үүрдийн харамсалтайгаар насан эцэслэдэг. Энэ бол бүх хүний өөр өөр байдал юм. Өргөн уудам хүний ертөнцийг харвал хүмүүс тасралтгүй урсгалаар ирж, буцдаг ба хэдий тэдэнд амьдрахаас илүү үхэхэд аз жаргалтай байх мэт санагддаг ч тэд хошуу нэмсээр байдаг бөгөөд хэн ч, хэзээ ч нас бараад буцан ирж, амьд хүмүүст үхлийн баяр хөөрийг хэрхэн эдлэхийг ярьж өгөн үлгэр дуурайл үзүүлээгүй. Хүмүүс бол зэвүүцмээр амьтад: Тэдэнд ямар ч ичгүүр, өөрсдийгөө хүндлэх хүндлэл байдаггүй бөгөөд үргэлж хэлсэн үгээсээ буцдаг. Өөрийнхөө төлөвлөгөөнд Бурхан, Өөрийнх нь амлалтыг эдлэх бүлэг хүмүүсийг урьдчилан тогтоосон ба тиймээс Бурхан, “Олон сүнс махан биед амьдарч, олон сүнс үхээд газар дээр дахин мэндэлсэн. Гэхдээ тэдний хэнд нь ч, хэзээ ч хаанчлалын ерөөлийг өнөөдөр эдлэх боломж олдоогүй” гэж хэлдэг. Өнөөдөр хаанчлалын ерөөлийг эдэлдэг бүхэн нь Бурхан дэлхий ертөнцийг бүтээснээс хойш Түүгээр урьдчилан тогтоогдсон юм. Энэ сүнснүүдийг эцсийн өдрүүдэд махан биед амьдруулахаар Бурхан зохицуулсан ба эцэстээ Бурхан энэ бүлэг хүмүүсийг авч, тэднийг Синимд байлгахаар зохицуулах болно. Мөн чанартаа энэ хүмүүсийн сүнс нь тэнгэр элч нар учраас Бурхан “Миний ямар ч ул мөр хүний сүнсэнд үнэхээр хэзээ ч байгаагүй гэж үү?” гэдэг. Үнэн хэрэгтээ, махан биед амьдарч байх үедээ хүмүүс сүнсний ертөнцийн хэрэг явдлын талаар тоохгүй хэвээр байдаг. Эдгээр энгийн үгээс Бурханы ааш занг харж болно: “хүн Над руу сэрэмжилсэн харц чулууддаг” хэмээх энэхүү энгийн үгс Бурханы нарийн ээдрээтэй сэтгэл зүйг илэрхийлдэг. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Бурханы зүрх сэтгэлд, уур хилэн болон шүүлтийг дагалдуулсан уй гашуу үргэлж байсаар ирсэн, учир нь “Хүн яг л уулын зэрлэг хүн шиг” хэмээн Бурханы хэлсэнчлэн газар дээрх хүмүүс Бурханы хүслийг анхаарах чадваргүй. Гэвч Бурхан бас “Хүчит далайгаас хүн Над руу сэлэх өдөр лавтай ирнэ, ингэснээр тэд газар дээрх бүх эд баялгийг эдэлж, тэнгист залгиулах эрсдэлийг ардаа орхих юм” гэдэг. Энэ бол Бурханы хүслийн биелэлт бөгөөд үүнийг бас зайлшгүй чиг хандлага гэж тодорхойлж болно, энэ нь Бурханы ажлын биелэлтийг бэлгэддэг.

Хаанчлал бүхэлдээ газар дээр бууж ирэх үед бүх хүн анхдагч дүр төрхөө эргүүлэн олж авна. Тиймээс Бурхан, “Би Өөрийн сэнтий дээр тааламжтай суун, оддын дунд амьдардаг. Тэнгэрэлчүүд Надад шинэ дуу, шинэ бүжиг өргөн барьж, дахин хэзээ ч өөрсдийнхөө хэврэг байдлын улмаас нулимс урсгахгүй. Миний өмнө тэнгэрэлчүүдийн уйлах чимээ дахин хэзээ ч сонсогдохоо больж, хэн ч Надад өөрсдийн зовлон бэрхшээлийг тоочихоо болино” гэж хэлдэг. Энэ нь, Бурхан бүрэн

гүйцэд алдрыг олж авах өдөр нь хүн өөрийн амралтыг эдлэх өдөр юм гэдгийг харуулдаг; хүмүүс цаашид Сатаны үймээнээс болж яаран гүйлдэхгүй ба дэлхий ертөнц урагшлан ахихаа больж, хүмүүс амралтад амьдарна—учир нь тэнгэрүүд дэх тоо томшгүй одод шинэчлэгдэж, нар, сар, одод гэх мэт болон тэнгэр, газар дахь бүх уул, гол бүгд өөрчлөгддөг. Мөн хүн өөрчлөгдөж, Бурхан өөрчлөгдсөн учраас бүх зүйл ч бас өөрчлөгдөх болно. Энэ бол Бурханы удирдлагын төлөвлөгөөний эцсийн зорилго бөгөөд эцэстээ биелэгдэх зүйл юм. Энэ бүх үгийг ярих Бурханы зорилго нь үндсэндээ хүнд Өөрийгөө мэдүүлэхийн төлөө билээ. Хүмүүс Бурханы захиргааны зарлигийг ойлгодоггүй. Бурханы хийдэг бүхэн Бурханаар Өөрөөр нь зохион байгуулагдаж, зохицуулагддаг ба Бурхан хэнийг ч хөндлөнгөөс оролцуулах хүсэлгүй байдаг; үүний оронд Тэрээр Бурхан бүхнийг зохицуулсан бөгөөд хүн биелүүлж чадашгүй гэдгийг харах боломжийг хүмүүст олгодог. Хэдийгээр хүн үүнийг харж чаддаг, эсвэл энэ нь төсөөлөхөд хэцүү санагддаг ч бүгдийг нь Бурхан ганцаараа хянадаг бөгөөд жаахан ч гэсэн хүний бодол холилдохыг Бурхан хүсдэггүй. Бурхан жаахан ч атугай оролцсон хэнийг ч өршөөхгүй нь дамжиггүй; Бурхан бол хүнд атаархдаг Бурхан бөгөөд энэ тал дээр Бурханы Сүнс нэн эмзэг байдаг юм шиг байна. Тиймээс хөндлөнгөөс оролцох санаатай хэн боловч өөрсдийг нь үнс нурам болгон хувиргах Бурханы бүхнийг залгигч галаар даруй хүрээлэгдэх болно. Бурхан, өөрсдийнхөө авьяас чадварыг хүссэнээрээ харуулахыг хүмүүст зөвшөөрдөггүй, учир нь авьяастай бүхэн амьгүй байдаг; эдгээр авьяас чадвар нь зөвхөн Бурханд үйлчлэх учиртай ба Сатанаас үүсэлтэй, тиймээс Бурхан ялангуяа үүнийг жигшиж, энэ талаар ямар ч буулт хийдэггүй. Гэвч амьгүй хүмүүс л ихэнхдээ Бурханы ажилд оролцож магадгүй байдаг бөгөөд үүнээс ч илүүтэйгээр тэдний оролцоо нь мэдэгдэлгүй үлддэг, учир нь тэдний авьяас чадвар үүнийг далдалдаг. Эрин үеүдийн туршид авьяас чадвартай хүмүүс хэзээ ч бат зогсож байгаагүй, учир нь тэд амьгүй бөгөөд тиймээс эсэргүүцэх хүч дутагдаж байдаг. Тиймээс Бурхан, “Хэрвээ Би илэн далангүй ярихгүй бол хүн хэзээ ч сэхээрэхгүй бөгөөд өөрийн мэдэлгүйгээр Миний гэсгээлтэд унана—учир нь хүн махбод дахь Намайг мэддэггүй билээ” гэдэг. Мах цуснаас бүтсэн бүхэн Бурханаар замчлуулдаг, гэхдээ бас Сатаны хүлээсэнд амьдарч байдаг, иймээс шунал тачаал, дур хүсэл, эсвэл хүрээлэн буй орчны зохицуулалтаас болж хүмүүс хэзээ ч нэг нэгэнтэйгээ хэвийн харилцаатай байгаагүй юм. Тийм хэвийн бус харилцаа нь Бурханы хамгийн их жигшдэг зүйл бөгөөд тийм харилцаанаас болж дараах үгс Бурханы амнаас гардаг: “Би амийн эрч хүчээр дүүрэн амьд амьтдыг хүсэж байгаа болохоос биш, үхэл нэвчсэн цогцоснуудыг хүсээгүй. Нэгэнт Би хаанчлалын ширээний ард заларсан учраас Миний хяналт шалгалтыг хүлээж авахыг газар дээрх бүх хүнд тушаана.” Бурхан бүхий л орчлон ертөнцийн дээр оршин байхдаа мах, цуснаас бүрдсэн хүмүүсийн үйлдэл нэг бүрийг өдөр бүр ажигладаг ба тэдгээрийн нэгийг нь ч, хэзээ ч орхигдуулаагүй. Эдгээр нь Бурханы үйл хэрэг билээ. Иймээс бүх хүн өөрсдийн бодол, санаа болон үйлдлийг шалган шинжлэхийг Би шавдуулдаг. Би чамаас Бурханы ичгүүрийн тэмдэг байхыг бус, харин Бурханы алдрын илрэл байж,

өөрийн үйлдэл, үг болоод амьдралд Сатаны тохуурхлын бай болохгүй байхыг хүсдэг. Энэ бол бүх хүнд тавих Бурханы шаардлага билээ.

21-Р БҮЛЭГ

Бурханы нүдэнд, хүмүүс амьтны ертөнц дэх амьтад шиг л байдаг. Тэд бие биетэйгээ тэмцэлдэж, бие биенээ хөнөөж, ер бусын байдлаар бие биетэйгээ харилцдаг. Бурханы нүдээр тэд бас, нас хүйснээс үл хамааран нэг нэгнийхээ эсрэг хуйвалддаг бичнүүдтэй адилхан байдаг. Тийм болохоор бүх хүн төрөлхтний хийдэг, илэрхийлдэг бүхэн хэзээ ч Бурханы зүрх сэтгэлийн дагуу байгаагүй. Бурхан Өөрийн нүүрийг халхлах цаг нь яг нарийндаа дэлхий даяарх хүмүүс туршигдах үе юм. Бүх хүн шаналан ёолж, бүгд гай гамшгийн заналхийлэл дор амьдардаг бөгөөд хэн ч, хэзээ ч Бурханы шүүлтээс зугтаж байгаагүй. Үнэндээ Бурхан махбод болохын үндсэн зорилго бол Өөрийн махбодоор хүнийг шүүж, яллах явдал юм. Гол чанараасаа хамааран хэн аврагдаж, эсвэл устгагдах вэ гэдэг нь Бурханы оюун санаанд аль хэдийн шийдэгдсэн бөгөөд энэ нь эцсийн үе шатанд аажмаар ил болно. Өдөр, сар өнгөрөхийн хэрээр хүмүүс өөрчлөгдөж, анхдагч хэлбэр дүрс нь илчлэгддэг. Өндгөнд тахиа байгаа юу, эсвэл нугас байгаа юу гэдэг нь хагарах үед илэрхий болдог. Өндөг хагарах үе нь газар дээрх гай гамшиг төгсгөлдөө очих яг тэр үе байх юм. Дотор нь “тахиа” байна уу “нугас” байна уу гэдгийг мэдэхийн тулд “өндгийг” хагалах ёстой гэдгийг үүнээс харж болно. Энэ бол Бурханы зүрх сэтгэл дэх төлөвлөгөө бөгөөд энэ нь гүйцэлдэх ёстой.

“Ядуу дорд, өрөвдмөөр хүн төрөлхтөн! Яагаад хүн Намайг хайрладаг ч Миний Сүнсний санаа зорилгыг дагаж чаддаггүй юм бэ?” Ийм байр байдлаасаа болоод хүн Бурханы хүслийг хангахын тулд харьцалт туулах ёстой. Хүн төрөлхтнийг үзэн ядсанаасаа болж Бурхан: “Өө бүх хүн төрөлхтний босогчид оо! Тэд Миний хөл дор няц гишгэгдэх ёстой; тэд Миний гэсгээлт дунд замхрах ёстой бөгөөд Миний агуу ажил үйлс бүрэн дуусах өдөр хүн төрөлхтний дундаас хөөгдсөн байх ёстой, ингэснээр бүх хүн төрөлхтөн тэдний үзэшгүй муухай нүүр царайг мэднэ” хэмээн олон удаа тунхагласан. Бурхан махбодоор бүх хүн төрөлхтөнтэй ярьж байгаа ба сүнсний ертөнцөд буюу бүхий л орчлон ертөнцийн дээр Сатантай ч бас ярьж байгаа. Энэ бол Бурханы хүсэл, энэ нь Бурханы 6,000 жилийн төлөвлөгөөгөөр биелэх учиртай зүйл юм.

Үнэндээ Бурхан тун хэвийн бөгөөд Түүнийг биечлэн хийж, Өөрийнхөө нүдээр харсан цагт л гүйцэлдэж болох зарим зүйл байдаг. Хүмүүсийн төсөөлдөг шиг Бурханыг хэвтэж байх зуур бүх зүйл хүссэнээр нь болдог юм биш; энэ нь Сатан хүмүүсийг үймүүлсний үр дагавар бөгөөд хүмүүс Бурханы үнэн царайг сайн мэдэхгүй байхад хүрдэг. Тийм болохоор сүүлчийн эрин үед Бурхан, юу ч нуулгүйгээр Өөрийн бодит байдлыг хүнд илэн далангүй илчлэхийн тулд махбод болсон. Бурхан ганцхан үгээр юм уу өчүүхэн төдий бодлоор л дэлхий ертөнцийг

устгаж чадна гэх мэтээр хэлсэн Бурханы зан чанарын тухай зарим дүрслэл нь цэвэр хэтрүүлэг юм. Үүний үр дүнд ихэнх хүмүүс, Бурхан бүхнийг чадагч мөртлөө яагаад Сатаныг ганцхан үмхэлтээр залгиж чаддаггүй юм бэ? гэх мэтийн зүйл хэлдэг. Ийм үг утгагүй бөгөөд хүмүүс Бурханыг мэдэхгүй хэвээр байгааг харуулдаг. Бурхан Өөрийн дайснуудыг устгахад үйл явц шаардагддаг боловч Бурхан бүхэлдээ ялгуусан гэж хэлэх нь зүйтэй: Бурхан эцсийн эцэст дайснуудаа ялна. Хүчирхэг улс буурай дорой улс орныг ялан дийлэх үедээ алхам алхмаар, заримдаа хүч хэрэглэж, заримдаа стратеги ашиглан ялалтад хүрэх ёстой байдагтай энэ нь адилхан. Үйл явц байдаг боловч хүчирхэг улс оронд шинэ үеийн цөмийн зэвсэг байдаг ба буурай улс орнууд хавьгүй илүү дор байдаг тул тэмцэхгүйгээр бууж өгнө гэж хэлж болохгүй. Тэр нь утгагүй дүгнэлт юм. Хүчирхэг улс орон гарцаагүй ялж, буурай улс орон гарцаагүй ялагддаг гэдгийг хэлэх нь зүйтэй боловч хүчирхэг улс орон буурай орон руу дайрч довтлох үедээ илүү хүчтэй байдаг гэж л хэлж болно. Тиймээс хүн Өөрийг нь мэддэггүй гэж Бурхан үргэлж хэлсээр ирсэн. Тэгвэл дээр буй үг хүн яагаад Бурханыг мэддэггүй вэ гэдгийн нэг талыг төлөөлдөг үү? Эдгээр нь хүний үзэл мөн үү? Бурхан яагаад хүнээс Өөрийнх нь бодит байдлыг болон биечлэн махбод болсныг нь мэдэхийг л хүсдэг вэ? Тиймээс ихэнх хүмүүс Тэнгэрт сүсэглэн мөргөсөн ч “Хүний үйлдлүүд тэнгэрт өчүүхэн төдий ч нөлөөлж байгаагүй бөгөөд хүнд хандах Миний хандлага түүний үйлдэл бүрд суурилдаг байсан бол бүх хүн төрөлхтөн Миний гэсгээлт дунд амьдрах байсан юм.”

Бурхан хүний гол чанарыг нэвт шувт хардаг. Бурханы айлдвараас харахад, Бурхан хүнээс болж маш их “тарчилсандаа” хүнд цаашид анхаарал хандуулах ямар ч сонирхолгүй болсон, түүнд өчүүхэн төдий ч найдахгүй байгаа мэт санагддаг; хүн аврагдахын аргагүй мэт санагддаг. “Нулимс хацрыг нь даган урсах олон хүнийг Би харсан бөгөөд Миний эд баялгийн хариуд зүрх сэтгэлээ өргөн барьсан олон хүнийг харсан. Тийм ‘үнэн сүсэгтэй байдал’-ыг үл харгалзан Би хүний гэнэтийн хүсэл эрмэлзлийн үр дүнд Өөрт байгаа бүхнийг хэзээ ч чөлөөтэй өгөөгүй, учир нь хүн Миний өмнө өөрийгөө баяртайяа зориулахад хэзээ ч бэлэн байгаагүй билээ.” Бурхан хүний уг чанарыг илчлэх үед хүн өөрөөсөө ичдэг боловч энэ нь ердөө өнгөцхөн мэдлэг бөгөөд Бурханы үгээс тэрээр өөрийнхөө уг чанарыг үнэхээр мэдэх чадваргүй юм; тиймээс ихэнх хүмүүс Бурханы хүслийг ойлгодоггүй, Бурханы үгээс өөрсдийнхөө амьдралын замыг олж чаддаггүй тул тэднийг мулгуу байх тусам, Бурхан төдий чинээ их тохуурхдаг. Тиймээс тэд өөрийн эрхгүй зэвүүн жигшүүртэй дүрд орж—үүний үр дүнд “зөөлөн үгээр” хутгалуунгаа өөрсдийгөө мэдэж авдаг. Бурханы үг хүний үйл хэргийг сайшааж, хүний үйл хэргийг урамшуулж байгаа мэт харагддаг—гэхдээ хүмүүст Бурхан өөрсдийг нь дооглож байна гэж санагддаг. Иймээс Бурханы үгийг унших үед таталт өгч байгаа мэтээр нүүрнийх нь булчин байн байн татвалздаг. Энэ бол тэдний мөс чанарын ариун бус байдал бөгөөд үүнээс болж тэд өөрийн эрхгүй татганадаг. Тэд инээхийг хүссэн ч инээж чаддаггүй, уйлахыг хүссэн ч уйлж чаддаггүй тийм шаналалтай байдаг, учир нь хүмүүсийн хөгийн байдлыг алсын удирдлагатай

“видео тоглуулагчаар” тоглуулдаг, харин тэд үүнийг унтрааж чадахгүй, гагцхүү тэвчиж л чадна. Хэдийгээр “Бурханы үгэнд анхаарлаа төвлөрүүлэхийг” хамтран зүтгэгчдийн цуглааны үеэр номлодог боловч агуу улаан лууны үр садын уг чанарыг мэдэхгүй хэн байх билээ? Нүүр тулан уулзахад тэд хурга мэт дуулгавартай байдаг боловч нүүр буруулах үед чоно мэт догширдог ба “Намайг үгээрээ хангахад олон хүн үнэн голоосоо Намайг хайрладаг ч Миний үгийг сүнсэндээ нандигнадаггүй, харин тэдгээрийг нийтийн өмч шиг хааш яаш ашиглаж, хүссэн үедээ ирсэн газар луу нь эргүүлээд шиддэг” хэмээх Бурханы үгээс үүнийг харж болно. Бурхан яагаад үргэлж хүнийг илчилсэн юм бэ? Хүний хуучин уг чанар тууштай, өөрчлөгдөшгүй байсан гэдгийг энэ нь харуулдаг. Энэ нь Тайшань уул шиг хэдэн зуун сая хүний зүрх сэтгэлд сүндэрлэн зогсож байдаг боловч Ю Гон[a] уг уулыг хөдөлгөх өдөр ирнэ; энэ нь Бурханы төлөвлөгөө билээ. Өөрийнхөө айлдвараар Бурхан хором бүрд хүнд шаардлага тавьж, хүнд анхааруулж, амьдралд нь илчлэгддэг хүний уг чанарыг зааж үзүүлдэг: “Хүн Надаас хол байх үед, Намайг турших үед Би үүлсийн дунд Өөрийгөө түүнээс нуудаг. Үүний үр дүнд тэр Миний ямар ч ул мөрийг олж чаддаггүй бөгөөд зөвхөн хорон муу нэгний гарт, хүссэн бүхнийг нь хийж амьдардаг.” Бодит байдал дээр хүмүүст Бурханы өмнө амьдрах боломж ховорхон байдаг, учир нь тэдэнд эрж хайх хүсэл хэтэрхий бага байдаг; үүний үр дүнд хэдийгээр ихэнх хүмүүс Бурханыг хайрладаг ч муу ёрын нэгний гарт амьдардаг бөгөөд тэдний хийдэг бүхнийг муу ёрын нэгэн залж чиглүүлдэг. Хэрвээ хүмүүс үнэхээр Бурханы гэрэлд амьдарч, өдөр бүр, хором бүрд Бурханыг эрж хайсан бол Бурхан ингэж ярих хэрэггүй байх байсан, тийм биз дээ? Хүмүүс бичвэрийг хойш тавих үедээ номтой хамтаар Бурханыг нэн даруй хойш тавьдаг тул өөрсдийнхөө л ажил хэргийг анхаардаг ба үүний дараа Бурхан тэдний зүрх сэтгэлээс алга болдог. Гэсэн ч номоо дахин барьж авах үедээ тэд Бурханыг умартсан гэдгээ гэнэтхэн санадаг. Энэ нь “ой санамжгүй” хүний амьдрал юм. Бурхан хэдий чинээ их ярина, Түүний үг төдий чинээ өндөр байдаг. Тэдгээр нь оргилдоо очих үед бүх ажил дуусах бөгөөд үүний үр дүнд Бурхан айлдваруудаа зогсоодог. Оргилдоо хүрэх үед нь Өөрийнхөө ажлыг төгсгөдөг нь Бурханы ажилладаг зарчим юм; ажил нь оргилдоо хүрмэгц Тэр үргэлжлүүлэн ажилладаггүй, харин шууд больдог. Тэрээр шаардлагагүй ажил хэзээ ч хийдэггүй.

22-Р БҮЛЭГ БА 23-Р БҮЛЭГ

Өнөөдөр, бүгд Бурханы хүслийг ухаарч, Бурханы зан чанарыг мэдэхийг хүсдэг ч, өөрсдийн хийхэд бэлэн зүйлээ яагаад хэрэгжүүлэх чадваргүй байдгаа, зүрх сэтгэл нь яагаад үргэлж өөрсдөөс нь урваж, хүссэн зүйлдээ яагаад хүрч чаддаггүй

[a] Ю Гон буюу “Өвгөн Ю” бол Хятадын ардын аман зохиолд гардаг домогт хүн юм. Ю уулыг хөдөлгөсөн тухай түүх нь харваас боломжгүй даалгавартай тулгараад цөхрөлтгүй байх явдлыг илэрхийлдэг.

вэ гэдгээ хэн ч мэддэггүй. Үүний улмаас тэд дахин нэгэнтээ хүнд цөхрөлд автдаг хэр нь бас айдастай байдаг. Эдгээр зөрчилдөөнтэй сэтгэл хөдлөлийг тэд илэрхийлж чадалгүй, гансран шаналахдаа толгой гудайлган, өөрсдөөсөө ийнхүү зогсолтгүй асууж л чадна: “Бурхан намайг гэгээрүүлээгүй юм гэж үү? Бурхан намайг сэмхэн хаясан юм гэж үү? Магадгүй бусад бүх хүн зүгээр байх, Бурхан надаас бусад бүх хүнийг гэгээрүүлсэн байх. Бурханы үгийг уншихаараа би яагаад дандаа үймэрдэг юм бэ, яагаад хэзээ ч, юуг ч ухаарч чаддаггүй юм бэ?” Хүмүүсийн толгойд ийм бодол эргэлддэг боловч, хэн нь ч үүнийгээ илэрхийлж зүрхэлдэггүй; зүгээр л дотроо чармайн тэмцсээр байдаг. Үнэндээ, Бурханаас өөр хэн ч Өөрийнх нь үгийг ойлгож, Өөрийнх нь жинхэнэ хүслийг ухаарч чадахгүй. Гэсэн ч, Бурхан Өөрийнх нь хүслийг ухаарахыг хүмүүсээс үргэлж шаарддаг—энэ нь нугасыг хөндөл дээр гаргахаар хүчлэн оролдохтой адил бус уу? Бурхан хүний дутагдлыг мэдэхгүй гэж үү? Энэ бол Бурханы ажлын зангилаа бөгөөд хүмүүс үүнийг ойлгодоггүй тул Бурхан “Хүн гэрэл дунд амьдардаг боловч гэрлийн эрхэм нандиныг мэддэггүй. Тэр гэрлийн мөн чанар, гэрлийн эх сурвалж, түүнчлэн гэрэл хэнд харьяалагддагийг мэддэггүй” гэж хэлдэг. Бурханы үгийн хүнд хэлж, хүнээс хүсдэг зүйлийн дагуу бол, хэн ч амьд үлдэхгүй, учир нь хүний махан биед Бурханы үгийг хүлээн зөвшөөрдөг юу ч байдаггүй. Иймээс Бурханы үгийг дуулгавартай дагаж, нандигнаж, Бурханы үгийг хүсэн эрмэлзэж, хүний байдлыг заасан Бурханы үгийг өөрсдийнхөө нөхцөл байдалд хэрэглэж, ингэснээр өөрсдийгөө мэдэж авч чаддаг байх нь хамгийн өндөр стандарт юм. Хаанчлал эцэстээ биеллээ олох үед, махан биед амьдардаг хүн, Бурханы хүслийг ухаарах чадваргүй хэвээр, Бурханы өөрийнх нь удирдамж шаардлагатай хэвээр байх болно—гэсэн ч хүмүүс зүгээр л Сатаны хөндлөнгийн оролцоогүй байж, хүний хэвийн амьдралтай байх болно; энэ бол Сатаныг ялах Бурханы зорилго, үүнийгээ Тэр гол нь Бурханы бүтээсэн хүний анхдагч мөн чанарыг сэргээхийн тулд хийдэг. Бурханы бодлоор, “махан бие” гэдэг нь дараах зүйлийг хэлдэг: Бурханы мөн чанарыг мэдэх чадваргүй байдал; сүнсний ертөнцийн хэрэг явдлыг харах чадваргүй байдал; түүнээс гадна, Сатанаар завхруулагддаг боловч Бурханы Сүнсээр удирдуулж чаддаг байх. Энэ бол Бурханы бүтээсэн махан биеийн мөн чанар билээ. Мэдээжийн хэрэг, энэ нь бас хүн төрөлхтний амьдралд дэг журам байхгүйн улмаас үүдэх эмх замбараагүй байдлаас зайлсхийхийн төлөө байдаг. Бурхан хэдий чинээ их ярьж, хэдий чинээ хурц тод ярих тусам хүмүүс төдий чинээ их ойлгодог. Хүмүүс өөрийн мэдэлгүй өөрчлөгдөж, өөрийн мэдэлгүй гэрэлд амьдардаг, тиймээс “Гэрлээс болж тэд өсөж байгаагийн дээр харанхуйг орхисон.” Хаанчлалын үзэсгэлэнтэй сайхан дүр зураг бөгөөд үргэлж яригдаж ирсэн “гэрэлд амьдарч, үхлээс хагацах” гэдэг нь энэ юм. Газар дэлхий дээр Синим биеллээ олох үед, хаанчлал биеллээ олох үед газар дээр дайн гарахаа болино; өлсгөлөн, тахал, газар хөдлөлт дахин хэзээ ч гарахгүй; хүмүүс зэр зэвсэг үйлдвэрлэхээ болино; бүгд амар тайван, тогтвортой байдалд амьдарна; хүмүүс хоорондоо хэвийн харилцаатай болж, улс орнууд хоорондоо хэвийн харилцаатай болно. Гэсэн

ч, одоо үеийг үүнтэй харьцуулшгүй. Тэнгэрийн доор бүгд эмх замбараагүй байх бөгөөд улс орон бүрд аажмаар төрийн эргэлт гарч эхэлж байна. Бурханы айлдварын үр дүнд хүмүүс аажмаар өөрчлөгдөж, улс орон бүр дотооддоо алгуурхнаар хуваагдаж байна. Вавилоны бат бэх суурь элсэн дээрх шилтгээн мэт ганхаж эхлэх бөгөөд Бурханы хүсэл өөрчлөгдөхөд дэлхий дээр анзаарагдалгүйгээр асар их өөрчлөлт гарч, бүх төрлийн тэмдэг хэзээд харагдаж, дэлхий ертөнцийн сүүлчийн өдөр ирснийг хүмүүст харуулдаг! Энэ бол Бурханы төлөвлөгөө; эдгээр нь Түүний ажилладаг алхмууд бөгөөд улс орон бүр гарцаагүй хэдэн хэсэг болон хуваагдана. Хуучны Содом хоёр дахь удаагаа газрын хөрснөөс арчигдана, тиймээс Бурхан “Дэлхий ертөнц нуран унаж байна! Вавилон саажилттай байна!” гэж хэлдэг. Бурханаас Өөрөөс нь өөр хэн ч үүнийг бүрэн ойлгох чадваргүй; эцсийн эцэст хүмүүсийн мэддэг зүйл хязгаартай юм. Жишээлбэл, дотоод хэргийн сайд нар өнөөгийн нөхцөл байдал тогтворгүй агаад эмх замбараагүй байгаа гэдгийг мэдэж байж магадгүй ч, тэд тэдгээрийг шийдвэрлэх чадваргүй юм. Тэд толгойгоо өндөрт өргөж чадах, нар дахин нэгэнтээ зүүнээс мандаж, газар нутгийг гийгүүлэн, энэхүү золгүй нөхцөл байдлыг буцаан өөрчлөх өдөр ирнэ гэж зүрх сэтгэлдээ найдан, урсгал даган хөвж л чадна. Гэхдээ, нар хоёр дахь удаагаа мандахад энэ нь хуучин дэг журмыг сэргээхийн тулд биш, харин дахин сэргэлт, бүрэн дүүрэн өөрчлөлт болно гэдгийг тэд огт мэддэггүй. Бүхий л орчлон ертөнцөд зориулсан Бурханы төлөвлөгөө ийм билээ. Тэр шинэ дэлхийг авчирна, гэхдээ юун түрүүнд, Тэр эхлээд хүнийг шинэчлэх болно. Өнөөдөр, хамгийн амин чухал зүйл нь хүмүүст зүгээр нэг байр суурины ерөөлийг эдлүүлэх биш, харин тэднийг Бурханы үгэнд оруулах юм. Түүнчлэн, Бурханы хэлдэгчлэн, “Хаанчлалд Би бол Хаан—гэхдээ Надад Хаан шиг хандахын оронд хүн Надтай ‘тэнгэрээс бууж ирсэн Аврагч’ шиг харьцдаг. Үүний улмаас өөрт нь өглөг өгөхийг тэр Надаас хүсэн хүлээж, Намайг мэдэхээр эрж хайдаггүй.” Бүх хүний жинхэнэ нөхцөл байдал ийм билээ. Өнөөдөр, хүний ханаж цаддаггүй шуналыг бүрмөсөн арилгаж, тэгснээрээ юу ч гуйлгүйгээр Бурханыг мэдэх боломжийг хүмүүст олгох нь нэн чухал юм. Тиймээс Бурхан “Маш олон хүн Миний өмнө гуйлгачин шиг гуйж гувшсан; маш олон хүн Надад ‘хүүдийгээ’ нээж, амь зуух хоол өгөхийг гуйсан” хэмээн хэлж байгаад гайхах хэрэггүй. Иймэрхүү байдал нь хүмүүсийн шуналыг илтгэж, хүмүүс Бурханыг хайрладаггүй, харин Түүнд шаардлага тавьж, эсвэл хүсэн тэмүүлдэг зүйлсээ олж авахыг хичээдэг гэдгийг нь харуулдаг. Хүмүүс өлсгөлөн чонын уг чанартай, тэд бүгд овжин агаад шунахай болохоор Бурхан, тэдэнд дахин нэгэнтээ шаардлага тавьж, ховдог шунахай сэтгэлээ орхиж, Бурханыг чин сэтгэлээсээ хайрлахыг хүчилдэг. Бодит байдал дээр өнөөг хүртэл хүмүүс бүх зүрх сэтгэлээ Бурханд хараахан өгөөгүй; хоёр туулай хөөж, Бурханыг бүрэн дүүрэн түшихгүйгээр, заримдаа өөрсдөдөө, заримдаа Түүнд найдаж байдаг. Бурханы ажил тодорхой хэмжээнд хүрэх үед бүх хүн жинхэнэ хайр, итгэл дунд амьдарч, Бурханы хүсэл биелэх болно; тиймээс Бурханы шаардлага өндөр биш билээ.

Тэнгэрэлчүүд тэнгэр, газрын хооронд яаравчлан, сүнсний ертөнцөд өдөр бүр эргэн очсоныхоо дараа хүний ертөнцөд буун ирж, Бурханы хөвгүүд, ардуудын дунд байнга явж байдаг. Энэ бол тэдний үүрэг учраас Бурханы хөвгүүд болон ардуудыг өдөр болгон хариулж, тэдний амь аажмаар өөрчлөгддөг. Бурхан Өөрийн хэлбэрийг өөрчлөх өдөр газар дээрх тэнгэрэлчүүдийн ажил албан ёсоор төгсөж, тэд тэнгэрийн ертөнцдөө эргэн очих болно. Өнөөдөр, Бурханы хөвгүүд, ардууд бүгд адилхан нөхцөл байдалд байгаа. Хором мөч өнгөрөхийн хэрээр бүх хүн өөрчлөгдөж, Бурханы хөвгүүд болон ардууд аажмаар төлөвшиж байгаа. Үүнтэй харьцуулахад, бүх тэрслэгч ч бас агуу улаан лууны өмнө өөрчлөгдөж байгаа: Хүмүүс агуу улаан луунд үнэнч байхаа больж, чөтгөрүүд зохицуулалтыг нь дагахаа больсон. Харин ч тэд “зохистой гэж үзсэнээ хийж, дор бүрнээ өөрсдийнхөө замаар явдаг.” Тиймээс Бурханыг “Газар дээрх улс орнууд мөхөхгүй байж яахан чадах билээ? Газар дээрх улс орнууд нуран унахгүй байж яахан чадах билээ?” хэмээн хэлэх үед дээд тэнгэрүүд нэн даруй доош бууж ирдэг… Энэ нь муу ёрын мэдрэмж хүн төрөлхтний төгсгөлийг ёрлож буй мэт байдаг. Энд зөгнөгдсөн янз бүрийн муу ёрын тэмдэг нь агуу улаан лууны оронд болж буй яг тэр зүйл бөгөөд газар дээрх хэн ч зугтааж чадахгүй. Бурханы үгэн дэх зөгнөл нь ийм билээ. Өнөөдөр бүх хүнд цаг хугацаа богино байна гэсэн совин төрж, гай гамшиг өөрсөд дээр нь ирэх гэж байгааг мэдэрдэг юм шиг санагддаг ч гэсэн тэд зугтах аргагүй учраас бүгд итгэл найдваргүй байдаг. Бурхан “Би Өөрийн хаанчлалын ‘дотоод өрөөг’ өдрөөс өдөрт чимэглэж байхад хэн ч, хэзээ ч Миний ажлыг тасалдуулахаар ‘ажлын өрөө’ рүү минь гэнэт дайран орж байгаагүй” гэж хэлдэг. Үнэндээ, Бурханы үгийн утга учир нь, хүмүүс Бурханыг үгээс нь мэдэж болно гэдгийг зүгээр нэг хэлэхэд оршдоггүй. Бүхнээс илүү, Өөрийн ажлын дараагийн хэсэгт үйлчлэх бүх төрлийн өрнөлийг Бурхан орчлон ертөнц даяар өдөр бүр зохицуулдаг гэдгийг тэдгээр нь илтгэдэг. Тэр “хэн ч, хэзээ ч Миний ажлыг тасалдуулахаар ‘ажлын өрөө’ рүү минь гэнэт дайран орж байгаагүй” хэмээн хэлсний учир шалтгаан нь Бурхан, бурханлаг чанараар ажилладагт байгаа бөгөөд хүмүүс хэдий хүссэн ч гэсэн Түүний ажилд оролцож чадахгүй. Би ингэж асуумаар байна: Чи бүх орчлон ертөнц дээрх өрнөл болгоныг үнэхээр зохицуулж чадах уу? Чи газар дээрх хүмүүсийг өвөг дээдсээ үл тоомсорлодог болгож чадах уу? Чи орчлон ертөнц даяарх хүмүүсийн аяыг нь олж Бурханы хүсэлд үйлчлүүлж чадах уу? Чи Сатаныг үймээн самуун дэгдээхэд хүргэж чадах уу? Чи дэлхий ертөнц эзгүй, хоосон гэж хүмүүст санагдуулж чадах уу? Хүмүүс тийм зүйл хийж чадахгүй. Өмнө нь, Сатан “ур чадвараа” хараахан бүрэн гаргаагүй байхдаа Бурханы ажлын үе шат бүрд үргэлж хөндлөнгөөс оролцдог байв; энэ үе шатанд Сатан заль мэхгүй болсон учраас Бурхан, бүх хүн үүнийг мэдээсэй гэсэндээ Сатанд үнэн дүр төрхөө харуулах боломжийг олгодог. Энэ бол “Хэн ч, хэзээ ч Миний ажлыг тасалдуулаагүй” гэдэг үгийн үнэн юм.

Чуулганы хүмүүс өдөр бүр Бурханы үгийг уншиж, өдөр бүр “хагалгааны ширээн” дээр задлан шинжлэх ажлыг туулдаг. Жишээлбэл, “албан тушаалаа алдах”,

“ажлаас халагдах”, “айдас нь дарагдаж тайвшрах”, “орхин явах”, “‘Сэтгэл хөдлөл’-гүй байх” гэх мэт доогтой үг нь хүмүүсийг “тарчлааж”, ичсэндээ тэнэг болгодог. Тэдний биеийн ямар ч хэсэг—толгойноосоо хөл хүртэл, дотроосоо гадагшаа—Бурханы сайшаалд нийцдэггүй мэт байдаг. Бурхан яагаад үгээрээ хүмүүсийн амьдралыг маш ил болгодог вэ? Бурхан юмыг санаатайгаар хүмүүст хэцүү болгож байгаа юу? Бүх хүний нүүрэн дээр угаагаад арилахааргүй шавар нялсан мэт байдаг. Тэд луйварчин шиг, толгой бөхийж, өдөр бүр нүглээ тайлагнадаг. Хүмүүс өөрсдийнхөө жинхэнэ байдлыг бүрэн мэдэхээргүй болтлоо Сатанаар завхруулагдсан. Гэвч Бурханы хувьд, Сатаны хор тэдний биеийн бүх хэсэгт, чөмгөнд нь хүртэл байдаг; үүний улмаас Бурханы илчлэл гүн гүнзгий байх тусмаа, хүмүүс улам айдастай болдог учраас бүх хүнд Сатаныг мэдүүлж, хүний дотор байгаа Сатаныг харуулдаг, учир нь тэд Сатаныг энгийн нүдээр харах чадваргүй байж ирсэн билээ. Ингээд бүгд бодит байдалд орсон тул, Бурхан хүний уг чанарыг ил болгодог—өөрөөр хэлбэл, Тэр Сатаны дүр төрхийг ил болгодог—тэгснээрээ бодит, биет Сатаныг харах боломжийг хүнд олгож, бодитой Бурханыг мэдэхэд тэдэнд хавьгүй дээр болдог. Бурхан махбод дахь Өөрийг нь мэдэх боломжийг хүнд олгож, Сатанд хэлбэр дүрс өгснөөрөө бүх хүний махан бие дэх бодит, биет Сатаныг мэдэх боломжийг хүнд олгодог. Яригдсан янз бүрийн байдал нь Сатаны үйлсийн илэрхийлэл юм. Иймээс махан биетэй бүх хүн, Сатаны дүр төрхийн биелэл гэж хэлж болно. Бурхан дайснуудтайгаа таардаггүй, тэд бие биедээ дайсагнадаг, хоёр өөр хүч учраас чөтгөр бол үүрд чөтгөр, Бурхан бол үүрд Бурхан байдаг; тэд гал ус шиг зохицолгүй, тэнгэр газар шиг үүрд салангид байдаг. Бурхан хүнийг бүтээх үед нэг төрлийн хүмүүст нь тэнгэрэлчүүдийн сүнснүүд байхад нөгөө төрөл нь сүнсгүй байсан, тиймээс сүүлийн төрөл нь чөтгөрүүдийн сүнсэнд эзэмдүүлсэн учраас чөтгөрүүд гэж нэрлэгджээ. Эцсийн эцэст тэнгэрэлч бол тэнгэрэлч, чөтгөр бол чөтгөр—Бурхан бол Бурхан юм. Энэ нь бүгд төрлийнхөө дагуу ангилагдах гэсэн үг, иймээс тэнгэрэлчүүд газар дээр хаанчилж, ерөөл эдлэх үед Бурхан Өөрийн амьдардаг газар луугаа эргэн очиж, бусад нь—Бурханы дайснууд—үнс нурам болдог. Үнэндээ, бүх хүн гаднаа Бурханыг хайрладаг мэт байдаг боловч, үндэс нь тэдний мөн чанарт оршдог—тэнгэрэлчийн уг чанартай хүмүүс яаж Бурханы гараас зугтаж, ёроолгүй нүхэнд унах юм бэ? Мөн чөтгөрийн уг чанартай хүмүүс яаж Бурханыг үнэхээр хайрлаж чадах юм бэ? Энэ хүмүүсийн мөн чанар нь Бурханыг гэх жинхэнэ хайрынх биш учраас тэд хэзээ нэгэн цагт хаанчлалд орох боломжтой болж яаж чадах юм бэ? “Салхи бороон дунд Би урагшилж, жил бүрийг хүмүүсийн дунд өнгөрөөж, өнөө үед ирлээ. Эдгээр нь чухамдаа Миний удирдлагын төлөвлөгөөний алхмууд биш гэж үү? Миний төлөвлөгөөнд хэн ер нь нэмэрлэсэн билээ? Миний төлөвлөгөөний алхмуудаас хэн зугтаж чадах билээ?” хэмээн Бурханы хэлсэнчлэн, Бурхан дэлхийг бүтээхдээ бүгдийг зохицуулсан. Махбод болсон болохоор Бурхан, хүний амьдралыг туулах ёстой, энэ нь бодитой Бурханы бодит тал бус уу? Бурхан хүний сул талаас болж, хүнээс юуг ч нуудаггүй; харин ч

яг л Бурханы “Би жил бүрийг хүмүүсийн дунд өнгөрөөж” хэмээн хэлсэнчлэн Тэр үнэнийг хүнд илчилж байдаг. Чухамхүү Бурхан бол махбод болсон Бурхан учраас л Тэр жил бүрийг газар дээр өнгөрүүлсэн; ийм болохоор, бүхий л төрлийн үйл явцыг туулсны дараа л Түүнийг, махбод болсон Бурхан гэж тооцож болно, зөвхөн үүний дараа л Тэр махбод дотор бурханлаг чанараар ажиллаж чаддаг. Тэгээд бүх нууцыг илчилснийхээ дараа л Тэр Өөрийн хэлбэрийг өөрчлөх эрх чөлөөтэй болно. Энэ нь ер бусын биш байх гэдгийн тайлбарын нөгөө тал нь бөгөөд үүнийг Бурхан шууд илтгэдэг.

Хааш яаш байхгүйгээр Бурханы үг нэг бүрийн шалгалтыг давах шаардлагатай—энэ бол Бурханы даалгавар билээ!

24-Р БҮЛЭГ БА 25-Р БҮЛЭГ

Сайтар уншихгүй бол энэ хоёр өдрийн айлдварууд аас юу ч олж илрүүлэх боломжгүй; үнэндээ тэдгээрийг нэг өдөрт ярих ёстой байсан ч Бурхан хоёр өдөрт хуваасан. Өөрөөр хэлбэл, энэ хоёр өдрийн айлдварууд нь нэгэн бүхэл зүйлийг бүрдүүлдэг боловч хүмүүс хүлээн авахад илүү амархан болгохын тулд Бурхан тэдгээрийг хоёр өдөрт хуваан хүмүүст амьсгаа авах боломж олгосон. Энэ нь хүнд тавих Бурханы анхаарал халамж билээ. Бурханы бүх ажилд бүх хүн тус тусын байрандаа үүрэг, даалгавраа гүйцэтгэдэг. Тэнгэрэлчийн сүнстэй хүмүүс л хамтран ажилладаг юм биш; чөтгөрийн сүнстэй хүмүүс ч бас “хамтран ажилладаг” ба Сатаны бүх сүнс ч хамтран ажилладаг. Бурханы айлдварууд аас Бурханы хүсэл болон хүнд тавих шаардлага нь харагддаг. “Миний гэсгээлт бүх хүн дээр ирдэг мөртөө бүх хүнээс хол хэвээр байдаг. Хүн бүрийн бүхий л амьдрал Надад хандах хайр, үзэн ядалтаар дүүрсэн байдаг” хэмээх үг нь Бурхан бүх хүнийг сүрдүүлэхийн тулд гэсгээлт ашиглаж, Өөрийнхөө талаарх мэдлэгийг тэдэнд олгодог гэдгийг харуулдаг. Сатаны завхрал болон тэнгэрэлчүүдийн хэврэг байдлын улмаас хүмүүсийг гэсгээхийн тулд Бурхан захиргааны зарлиг биш, харин зөвхөн үг ашигладаг. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл энэ нь тэнгэрэлчүүд болон бүх хүнтэй холбоотой Бурханы ажлын зарчим байсаар ирсэн юм. Тэнгэрэлчүүд Бурханых учраас нэг л өдөр тэд гарцаагүй Бурханы хаанчлалын ардууд болж, Бурханаар халамжлуулж, хамгаалуулна. Харин тэгэхэд бусад нь ч бас төрлийнхөө дагуу ангилагдана. Сатаны янз бүрийн муу ёрын сүнснүүд гэсгээгдэж, сүнсгүй бүхнийг Бурханы хөвгүүд, ардууд удирдана. Энэ нь Бурханы төлөвлөгөө билээ. Тиймээс Бурхан нэгэнтээ “Миний өдөр ирэх нь үнэхээр хүний үхэх мөч гэж үү? Миний хаанчлал бий болох үед Би үнэхээр хүнийг устгах юм гэж үү?” хэмээн хэлсэн юм. Хэдий энэ нь энгийн хоёр асуулт боловч бүх хүн төрөлхтний хүрэх газрын төлөөх Бурханы зохицуулалт билээ. Бурхан хүрэлцэн ирэх үе нь “орчлон ертөнц даяарх хүмүүс доош харан загалмайд цовдлогдох” үе юм. Энэ нь Бурхан бүх хүнд

харагдаж, Бурханы оршин тогтнолыг мэдэгдэхийн тулд гэсгээлт ашигладгийн зорилго билээ. Бурхан газар дээр бууж ирдэг үе нь эцсийн эрин үе, мөн газар дээрх улс орнууд хамгийн их үймээн самуунтай байдаг үе учраас Бурхан: “Намайг газар дээр бууж ирэхэд харанхуй нөмөрсөн бөгөөд хүн ‘бөх унтаж’ байдаг” гэж хэлсэн. Тийм болохоор өнөөдөр бие махбодтой болсон Бурханыг мэдэх чадвартай хүмүүс маш цөөхөн, бараг нэг ч байдаггүй. Одоо үе бол эцсийн эрин үе учраас хэн ч, хэзээ ч бодитой Бурханыг үнэхээр мэдээгүй бөгөөд хүмүүс Бурханы талаар өнгөцхөн л мэдлэгтэй байдаг. Үүнээс болоод хүмүүс шаналгаат цэвэршүүлэлт дунд амьдардаг. Хүмүүс цэвэршүүлэлтийг орхих үе нь бас тэдний гэсгээгдэж эхлэх үе, мөн Бурхан бүх хүнд харагддаг үе юм, ингэснээр тэд Түүнийг нүдээрээ харж магадгүй. Бие махбодтой болсон Бурханаас үүдэн хүмүүс гамшигт унаж, өөрсдийгөө чөлөөлөх чадваргүй байдаг—энэ нь агуу улаан лууг шийтгэх Бурханы шийтгэл бөгөөд Түүний захиргааны зарлиг билээ. Хаврын урин дулаан ирж, цэцэгс дэлгэрч, тэнгэрийн доорх бүхэн ногоон өнгөөр бүрхэгдэж, газар дээрх бүх зүйл байрандаа байх үед, бүх хүн болон зүйл аажмаар Бурханы гэсгээлтэд орно, тэр үед Бурханы газар дээрх бүх ажил төгсөнө. Бурхан газар дээр ажиллаж, амьдрахаа болино, учир нь Бурханы агуу ажил гүйцэлдсэн байх болно. Хүмүүс энэ богинохон хугацаанд махан биеэ хойш тавих чадваргүй юү? Хүн, Бурхан хоёрын хоорондох хайрыг ямар зүйлс сэвтээж чадах вэ? Хүн, Бурхан хоёрын хайрыг хэн салгаж чадах юм бэ? Эцэг эх, нөхрүүд, эгч нар, эхнэрүүд, эсвэл шаналгаат цэвэршүүлэлт үү? Хүний доторх Бурханы дүрийг мөс чанарын мэдрэмж арчин хаяж чадах уу? Хүмүүсийн өртэй байдал, бие биедээ хандсан үйлдэл нь өөрсдийнх нь хийж байгаа зүйл мөн үү? Тэдгээрийг хүн засаж залруулж чадах уу? Хэн өөрийгөө хамгаалж чадах вэ? Хүмүүс өөрсдийгөө хангаж чадах уу? Амьдрал дахь хүчтэй хүмүүс хэн бэ? Хэн Намайг орхиж, бие даан амьдарч чадах вэ? Өөрийгөө эргэцүүлэх ажил хийхийг Бурхан яагаад бүх хүнээс ахин дахин шаарддаг вэ? Яагаад Бурхан: “Хэний зовлон зүдүүр өөрсдийнх нь гараар зохицуулагддаг вэ?” хэмээн хэлдэг вэ?

Одоогоор орчлон ертөнц даяар харанхуй шөнө байгаа ба хүмүүс хөшүүн, мангуу боловч цагийн зүү үргэлж урагшилж, минут секунд нь зогсдоггүй ба дэлхий, нар, сарны эргэлт хурдасдаг. Өөрсдийн мэдрэмжээр хүмүүс тэр өдөр холгүй гэж боддог; өөрсдийнх нь сүүлчийн өдөр нүднийх нь өмнө байгаа мэт байдаг. Хүмүүс үхэх мөчид нь хэрэг болно гэсэндээ үхэх цагтаа зориулж бүх зүйлийг тасралтгүй бэлддэг; эс бөгөөс тэд хий дэмий амьдарсан байх болно. Тэгвэл харамсалтай бус уу? Бурхан дэлхийг устгах үедээ улс орнуудын дотоод хэрэг явдлын өөрчлөлтөөс эхэлдэг, эндээс төрийн эргэлт гардаг; тийнхүү Бурхан орчлон ертөнц даяарх хүмүүсийн үйлчлэлийг дайчилдаг. Агуу улаан лууны цагариглан хэвтэж буй газар нь үзүүлэнгийн бүс нутаг юм. Дотооддоо хуваагдсан учраас үүний дотоод хэрэг явдал эмх замбараагүй болж, хүн бүр өөрийгөө хамгаалах ажил хийж, сар луу зугтахаар бэлдэж байгаа—гэвч тэд Бурханы гарын ноёрхлоос яахан зугтаж чадах билээ? Бурханы хэлсэнчлэн хүмүүс “өөрсдийнхөө гашуун зовлонгийн аяганаас л

уух болно.” Дотоод тэмцлийн цаг үе нь чухамдаа Бурхан газар дэлхийгээс явдаг үе юм; Бурхан агуу улаан лууны оронд үргэлжлүүлэн үлдэхээ больж, газар дээрх ажлаа нэн даруй төгсгөнө. Цаг хугацаа нисэн оддог бөгөөд тийм ч их цаг үлдээгүй гэж хэлж болно. Бурхан орчлон ертөнц даяарх бүх хүний хүрэх газрын талаар аль хэдийн ярьсан ба үлдсэнийх нь талаар өөр ярих юм байхгүй гэдгийг Бурханы үгийн өнгө аясаас харж болно. Энэ бол хүнд Бурханы илчилдэг зүйл юм. Хүнийг бүтээсэн зорилгоосоо болоод Бурхан: “Миний нүдэнд хүн бол бүх зүйлийн захирагч юм. Би түүнд багагүй хэмжээний эрх мэдэл өгч, газар дээрх бүх зүйл, уулан дээрх өвс ургамал, ой модон доторх амьтад, усан дахь загас зэргийг хүнээр удирдуулсан” гэж хэлсэн билээ. Бурхан хүнийг бүтээх үедээ хүн бол бүх зүйлийн эзэн байх болно гэж урьдчилан тогтоосон—гэсэн ч хүнийг Сатан завхруулсан тул тэр өөрийнхөө хүссэнээр амьдарч чаддаггүй. Энэ нь өнөөгийн дэлхийд хүргэсэн, энд хүмүүс нь араатнаас өөрцгүй, уулс голтой холилдсон байдаг бөгөөд үр дүнд нь “хүний бүхий л амьдрал шаналгаатай, яарч сандарсан, хоосон байдалд зугаа цэнгэл нэмсэн зүйл болсон.” Хүний амьдрал ямар ч утга учиргүй учраас, энэ нь хүнийг бүтээсэн Бурханы зорилго биш учраас бүхий л дэлхий ертөнц ээдрээтэй болсон. Бурхан бүхий л орчлон ертөнцийг дэг журамд оруулах үед бүх хүн албан ёсоор хүний амьдралыг туулж эхлэх ба тэр үед л амьдрал нь утга учиртай болж эхэлнэ. Хүмүүс өөрсдөд нь Бурханы өгсөн эрх мэдлийг хэрэглэж эхлэх бөгөөд бүх зүйлийн өмнө албан ёсоор эзэн нь болон гарч ирнэ; тэд Бурханы удирдамжийг газар дээр хүлээн авч, Бурханд дуулгаваргүй байхаа болиод, харин Бурханд дуулгавартай байх болно. Гэхдээ өнөөдрийн хүмүүс ердөө ч тийм биш. Тэдний хийдэг бүхэн нь Бурханаар дамжуулан “хувьдаа мөнгө саах” явдал тул Бурхан “Хүн дээр Миний хийдэг ажил түүнд ашиг тусгүй байдаг гэж үү?” гэх мэтийн цуврал асуулт асуудаг. Хэрвээ Бурхан энэ асуултуудыг асуугаагүй бол юу ч тохиолдохгүй байх байсан; гэхдээ Түүнийг ийм зүйл асуух үед зарим хүн бат зогсож чаддаггүй, учир нь хүмүүсийн мөс чанарт өр шир байдаг бөгөөд тэр нь дан ганц Бурханы төлөө биш, харин өөрсдийнх нь төлөө байдаг. Бүх зүйл хий хоосон; тиймээс энэ хүмүүс болон “бүх шашин, нийгмийн хүрээ, улс үндэстэн, шашны урсгал бүрийн хүмүүс бүгдээрээ газар дээрх хоосон байдлыг мэднэ, тэд бүгдээрээ Намайг эрж хайж, Намайг эргэн ирэхийг хүлээдэг.” Бурхан хоосон, хуучин эрин үеийг төгсгөл болгоно гэсэндээ бүх хүн Бурханы эргэн ирэлтийг хүсэн тэмүүлдэг ч бас гай гамшигт унахаас эмээдэг. Бүхий л шашны ертөнц нэн даруй эзгүйрэн үлдэж, бүгдэд үл ойшоогдоно; тэдэнд бодит байдал байдаггүй ба Бурханд итгэх итгэл нь тодорхойгүй, бүдэг бадаг гэдгийг тэд ухаарна. Нийгмийн давхарга болгоны хүмүүс ч бас сарнин бутарч, бүх үндэстэн болон урсгал үймээн самуунд автаж эхэлнэ. Дүгнэн хэлбэл, бүх зүйлийн зүй тогтол алдагдаж, бүгд хэвийн байдлаа алдах тул хүмүүс ч бас үнэн нүүр царайгаа илчилнэ. Тиймээс Бурхан: “Би хүн рүү олон удаа хашхирсан атал хэн нэгэн ер нь өрөвдөж байсан уу? Хүн чанартайгаар амьдарч байсан хүн ер нь байна уу? Хүн махан биетэй амьдардаг боловч хүн чанаргүй юм. Тэрээр амьтны ертөнцөд төрсөн

гэж үү?” гэдэг. Хүмүүсийн дунд ч бас өөрчлөлт гарч байгаа бөгөөд энэхүү өөрчлөлтийн улмаас бүгд төрлийнхөө дагуу ангилагддаг. Энэ бол эцсийн өдрүүд дэх Бурханы ажил бөгөөд эцсийн өдрүүдийн ажлаар хүрэх ёстой үр нөлөө юм. Бурхан хүний мөн чанарын талаар илүү тодорхой ярьдаг тул Түүний ажлын төгсгөл ойртож байгааг энэ нь нотолдог, түүнчлэн Бурхан хүмүүсээс улам нуугдмал байж, хүмүүсийг улам сандраадаг. Хүмүүс Бурханы хүслийг улам бага ажиглаж, эцсийн өдрүүдийн Бурханы ажилд анхаарал хандуулах нь улам багасдаг; энэ нь тэдний саад болохыг болиулдаг бөгөөд тэгснээр Бурхан хэнийг ч анхаарал хандуулаагүй байх үед Өөрийнхөө зорьсон ажлыг хийдэг. Энэ бол эрин үеүдийн турш дахь Бурханы ажлын нэг зарчим билээ. Тэрээр хүмүүсийн сул талыг үл хайхрах тусам, Бурханы бурханлаг чанар улам илэрхий харагддаг тул Бурханы өдөр илүү их ойртдог.

26-Р БҮЛЭГ

Өдөр хоног өнгөрөхийн хэрээр Бурханы өдөр ойртож байгааг Бурханы хэлсэн бүх үгээс харж болно. Энэ өдөр яг хүмүүсийн нүдний өмнө байгаа мэт, энэ нь маргааш хүрэлцэн ирэх юм шиг байдаг. Тиймээс Бурханы үгийг уншсаны дараа бүх хүн айдаст автан, навчис салхинд унаад, зөөлөн бороо шивэрсэн дэлхий ертөнцийн эзгүйрлийн нэг хэсгийг бас мэдэрдэг. Хүмүүс бүгд тэр чигтээ сураггүй арилсан мэт ул мөргүй алга болдог. Хүн бүрд муу ёрлосон мэдрэмж төрдөг ба хэдий бүх хүн шаргуу хичээж, Бурханы хүслийг хангахыг хүсэж, Бурханы хүслийг төвөггүй, саадгүй урагшлуулах гэсэндээ дор бүрнээ Бурханы санаа зорилгыг биелүүлэхийн тулд хамаг чадлаа ашигладаг ч тийм сэтгэл нь муу ёрын мэдрэмжтэй үргэлж холилдож байдаг. Өнөөдрийн айлдваруудыг аваад үз: Хэрвээ тэдгээрийг олон нийтэд цацаж, бүхий л орчлон ертөнцөд зарласан бол бүх хүн нүүрээрээ газар унан мөргөж, уйлах байв, учир нь “Би бүхий л газар дэлхийг ажиглан харж, зөвт байдал, сүр жавхлан, уур хилэн болон гэсгээлттэйгээр ертөнцийн зүүн зүгт гарч ирж, тоймгүй олон хүнд Өөрийгөө илчилнэ!” хэмээх үгээс, хэн ч Бурханы гэсгээлтээс зугтаж чадахгүй бөгөөд гэсгээлтийн зовлонг туулсны дараа бүгд төрлийнхөө дагуу ангилагдана гэдгийг сүнслэг хэрэг явдлыг ойлгодог бүх хүн хардаг. Энэ бол үнэхээр Бурханы ажлын алхам бөгөөд хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Бурхан дэлхийг бүтээх үедээ, хүн төрөлхтнийг удирдан хөтлөх үедээ Өөрийнхөө мэргэн ухаан, гайхалтай байдлыг харуулсан ба Тэрээр энэ эринийг төгсгөх үед л хүмүүс Түүний жинхэнэ зөвт байдал, сүр жавхлан, уур хилэн, гэсгээлтийг харна. Түүнчлэн зөвхөн гэсгээлтээр л дамжуулан тэд Түүний зөвт байдал, сүр жавхлан, уур хилэнг харж чаддаг; эцсийн өдрүүдэд Бурхан бие махбодтой болох шаардлагатай, зайлшгүй хэрэгтэй байдаг шиг энэ бол явах ёстой зам юм. Бүх хүн төрөлхтний төгсгөлийг тунхагласны дараа Бурхан өнөөдөр хийдэг

ажлаа хүнд харуулдаг. Жишээлбэл, Бурхан: “Хуучны Израиль үгүй болж, өнөөгийн Израиль дэлхий дээр өндийн, сүндэрлэн байгуулагдаж, бүх хүний зүрх сэтгэлд бослоо. Өнөөдрийн Израиль Миний ардуудаар дамжуулан оршин тогтнолын эх үүсвэрт гарцаагүй хүрнэ!” “Аяа, заналт Египет ээ! … Миний гэсгээлт дотор оршихгүй байж яаж чадах юм бэ?” гэж хэлсэн. Хоёр эсрэг тэсрэг улс орны Бурханы гараас хүртсэн үр дагаврыг Бурхан хүмүүст зориуд харуулдаг, нэг талаараа материаллаг Израилийг хэлж байгаа ба нөгөө талаараа Бурханы сонгосон бүх хүнийг буюу Израиль өөрчлөгдөхийн хэрээр Бурханы сонгосон хүмүүс хэрхэн өөрчлөгддөгийг хэлж байгаа. Израиль анхдагч байдалдаа бүрэн буцаж очих үед сонгогдсон бүх хүн дараа нь бүрэн төгс болгуулна—өөрөөр хэлбэл, Израиль нь Бурханы хайртай хүмүүсийн хувьд утга учиртай бэлгэ тэмдэг билээ. Харин Египет бол Бурханы үзэн яддаг хүмүүсийн төлөөлөгчдийн нийлэмж юм. Энэ нь доройтон муудах тусам, Бурханы үзэн яддаг хүмүүс улам их завхардаг—дараа нь Вавилон нуран унадаг. Энэ нь тодорхой ялгааг бий болгодог. Израиль болон Египетийн төгсгөлийг тунхагласнаараа Бурхан бүх хүний хүрэх газрыг илчилдэг; тиймээс Израилийг дурдах үедээ Бурхан Египетийн талаар ч бас ярьж байдаг. Египетийн сүйрлийн өдөр бол дэлхий ертөнц устгагдах өдөр, Бурхан бүх хүнийг гэсгээх өдөр юм гэдгийг үүнээс харж болно. Энэ нь удахгүй тохиолдоно; Бурхан үүнийг гүйцэлдүүлэх гэж байгаа бөгөөд энэ нь хүний энгийн нүдэнд харагдашгүй атлаа зайлшгүй хэрэгтэй, өөрчлөгдөшгүй зүйл юм. Бурхан: “Миний эсрэг зогсдог бүхнийг Би мөнхөд гэсгээх нь гарцаагүй. Учир нь Би хартай Бурхан бөгөөд хийсэн бүхнийх нь төлөө хүмүүсийг амархан хэлтрүүлэхгүй” гэж хэлсэн. Яагаад Бурхан ийм туйлын нөхцөлтэйгээр ярьдаг вэ? Тэр яагаад агуу улаан лууны улс оронд биечлэн махбод болсон бэ? Бурханы үгээс Өөрийнх нь зорилгыг харж болно: Тэрээр хүмүүсийг аврахын тулд, тэдэнд өршөөл энэрэл үзүүлэхийн тулд, эсвэл тэднийг халамжилж, хамгаалахын тулд ирээгүй—харин Өөрийг нь эсэргүүцдэг бүх хүнийг гэсгээхийн тулд ирсэн. Учир нь Бурхан: “Хэн ч Миний гэсгээлтээс зугтаж чадахгүй” гэж хэлдэг. Бурхан махбодод амьдардаг, түүнчлэн Тэр бол хэвийн хүн, гэхдээ Өөрийг нь субьектив байдлаар мэдэж чадахгүй байгаа сул талынх нь төлөө хүмүүсийг уучилдаггүй; харин Тэрээр “хэвийн хүний” арга барилаар нүглийнх нь төлөө хүмүүсийг яллаж, Өөрийнх нь махбодыг хардаг хүмүүсийг гэсгээгдэх хүмүүс болгодог бөгөөд тиймээс тэд агуу улаан лууны улс орныхоос бусад бүх хүний төлөөх золиос болдог. Гэхдээ энэ нь Бурхан бие махбодтой болохын үндсэн зорилгуудын нэг биш юм. Бурхан махбодоор агуу улаан луутай тулалдаж, тулаанаар дамжуулан түүнд ичгүүр авчрахын тулд л үндсэндээ махбод болсон. Агуу улаан луутай Сүнсээр биш, харин махбодоор тулалдсанаар Бурханы агуу хүч чадал илүү их нотлогддог ба Өөрийн үйл хэрэг, бүхнийг чадагч байдлыг харуулахын тулд Бурхан махбодоор тулалддаг. Бурхан бие махбодтой болсноос үүдэн тоймгүй олон хүн “гэмгүйгээр” яллагдсан, улмаар тоо томшгүй олон хүн там руу шидэгдэж, гэсгээлтэд хаягдаж, махан биеэр зовж байгаа. Энэ бол Бурханы зөвт

зан чанарын баталгаа бөгөөд Бурханыг эсэргүүцдэг хүмүүс өнөөдөр хэрхэн өөрчлөгдөхөөс үл хамааран, Бурханы шударга зан чанар хэзээ ч өөрчлөгдөхгүй. Нэгэнт яллагдмагцаа хүмүүс хэзээ ч дахин өндийн босож чадалгүй, үүрд яллагддаг. Хүний зан чанар нь Бурханых шиг байж чадахгүй. Бурханыг эсэргүүцдэг хүмүүст хандахдаа хүмүүс ээлжлэн туйлширдаг; тэд баруун, зүүн тийш, дээш, доош ганхан хэлбэлздэг; мөн байнга нэгэн хэвийн байх чадваргүй байдаг бөгөөд заримдаа Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийг голдоо ортол үзэн ядаж, заримдаа тэднийг ойр дотно байлгадаг. Хүмүүс Бурханы ажлыг мэддэггүйгээс болж өнөөдрийн нөхцөл байдал бий болсон. Яагаад Бурхан: “Тэнгэрэлч бол эцсийн эцэст тэнгэрэлч; Бурхан бол эцсийн эцэст Бурхан; чөтгөр бол эцсийн эцэст чөтгөр; зөв шударга бус хүмүүс нь зөв шударга бус; ариун хүмүүс мөн л ариун” гэх мэт үгийг хэлдэг вэ? Та нар үүнийг ойлгож чадахгүй байна уу? Бурхан сайн санахгүй байсан байж таарах уу? Тиймээс Бурхан: “Хүн бүр төрлийнхөө дагуу ангилагдаж, өөрийн мэдэлгүй гэр бүлийнхнийхээ тэвэрт буцан очих замаа олно” гэж хэлсэн. Өнөөдөр Бурхан аль хэдийн бүх зүйлийг гэр бүлүүд рүү нь ангилсан бөгөөд ингэснээр энэ нь “хязгааргүй ертөнц” байхаа больж, хүмүүс нэгэн том тогооноос идэхээ болиод, харин өөрсдийнхөө гэрт үүргээ биелүүлж, өөрсдийнхөө дүрд тоглодог гэдгийг үүнээс харж болно. Энэ нь дэлхий ертөнцийг бүтээх үеийн Бурханы анхдагч төлөвлөгөө байв; төрлийнхөө дагуу ангилагдсаныхаа дараа хүмүүс “дор бүрнээ өөрсдийнхөө хоолыг иднэ”, өөрөөр хэлбэл, Бурхан шүүлтээ эхэлнэ. Үүний үр дүнд Бурханы амнаас эдгээр үг гарсан юм: “Би бүтээлийн хуучин байр байдлыг сэргээнэ; Би бүх зүйлийг анхдагч байдалд нь оруулж, бүхнийг гүн гүнзгий өөрчилнө, ингэснээр бүх зүйл Миний төлөвлөгөөнд эргэж ирнэ.” Энэ нь чухамдаа Бурханы бүх ажлын зорилго бөгөөд үүнийг ойлгоход хэцүү биш. Бурхан Өөрийн ажлыг дуусгана—хүн Түүний ажилд саад учруулж чадах уу? Бурхан хүнтэй байгуулсан гэрээгээ цуцалж чадах уу? Бурханы Сүнсний хийсэн зүйлийг хэн өөрчилж чадах юм бэ? Хэн нэгэн хүн өөрчилж ер нь чадах уу?

Урьд нь хүмүүс Бурханы үгээс хуулийг ухаарсан юм: Бурханыг үг хэлмэгц удалгүй биелдэг байлаа. Үүнд ямар ч худал хуурмаг байхгүй. Бурхан бүх хүнийг гэсгээнэ гэж хэлсэн учраас, түүнчлэн захиргааны зарлигаа гаргасан учраас Бурханы ажил тодорхой үе шатанд хэрэгжсэн гэдгийг харж болно. Бүх хүнд зориулж гаргасан үндсэн хууль нь тэдний амьдрал болон Бурханд хандах хандлагад чиглэсэн байв. Энэ нь эх сурвалжийг нь хөндөөгүй; Бурханы урьдчилан тогтоолтод үндэслэсэн гэж хэлээгүй, харин тухайн үеийн хүний ааш авирт үндэслэсэн билээ. Өнөөдрийн захиргааны зарлиг ер бусын байдаг бөгөөд “бүх хүн төрлөөрөө ангилагдаж, өөрсдийнхөө үйлдэлд тохирсон гэсгээлтийг хүртэх” тухай хэлдэг. Сайтар уншихгүй бол эндээс ямар ч асуудал олж чадахгүй. Сүүлчийн эрин үед л Бурхан бүх зүйлийг төрлийнх нь дагуу ангилдаг учраас үүнийг уншсаныхаа дараа ихэнх хүн төөрөлдөж, будилсан хэвээр үлддэг; тэд хайхрамжгүй хандлага баримталсаар, цаг давчуу байгааг хардаггүй тул үүнийг анхааруулга гэж авч

үздэггүй. Энэ үед, бүхий л орчлон ертөнцөд тунхаглагдсан Бурханы захиргааны зарлигыг яагаад хүнд харуулдаг юм бэ? Энэ хүмүүс орчлон ертөнц даяарх бүх хүнийг төлөөлдөг үү? Дараа нь Бурхан энэ хүмүүст илүү их өршөөл үзүүлдэг юм гэж үү? Энэ хүмүүст хоёр толгой ургаа юу? Бурхан бүхий л орчлон ертөнцийн хүмүүсийг гэсгээх үед, бүх төрлийн гамшиг тохиох үед эдгээр гамшгийн улмаас нар сар хоёрт өөрчлөлт гарах ба эдгээр гамшиг төгсөхөд нар сар хоёр өөрчлөгдсөн байх болно—үүнийг “шилжилт” гэж нэрлэдэг. Хожмын гамшиг ноцтой байх болно гэж хэлэхэд хангалттай. Өдөр нь шөнөөр солигдох, жилийн турш нар үзэхээ болих, хэдэн сарын турш төөнөсөн халуун болох, хүн төрөлхтөн бөхөж буй сартай үргэлж тулгарах, нар сар зэрэг мандах гэх мэт хачин жигтэй байдал ч гарч болзошгүй. Хэд хэдэн мөчлөгтэй өөрчлөлтийг дагаад, цаг хугацаа өнгөрөхийн хэрээр эцэстээ тэдгээр нь шинэчлэгдэх болно. Диаволд харьяалагддаг хүмүүст зориулсан төлөвлөгөөндөө Бурхан онцгой анхаарал хандуулдаг. Тиймээс Тэр: “Орчлон ертөнц дэх хүмүүсээс диаволд харьяалагддаг бүх хүн устана” гэж зориуд хэлдэг. Энэ “хүмүүс” үнэн нүүр царайгаа харуулахаас өмнө Бурхан үргэлж тэдний үйлчлэлийг ашигладаг; үүний үр дүнд Тэр тэдний хийж байгааг огт анхаардаггүй ба тэднийг сайн хийх үед ямар ч “шагнал” өгдөггүй, мөн муухан хийхэд нь ч “цалинг” нь хасдаггүй. Тийнхүү Тэр тэднийг үл тоомсорлож, тэдэнд хүйтэн хөндий ханддаг. Тэдний “сайн сайхнаас” болж Тэр гэнэтхэн өөрчлөгддөггүй, учир нь Бурхан хүн хоёрын хоорондох гэрээний адилаар, “тэнгис хатаж, хад үйрч байсан ч гэсэн ямар ч өөрчлөлт гарахгүй” хэмээн хүний хэлдгийн адилаар цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүний мөн чанар өөрчлөгддөггүй. Тиймээс Бурхан зүгээр л тэр хүмүүсийг төрлийнх нь дагуу ангилдаг бөгөөд тэднийг амархан анхаардаггүй. Бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөг хүртэл диавол хэзээ ч биеэ сайн авч явж байгаагүй. Тэр үргэлж саад болж, үймүүлж, санал зөрж байсан. Бурханыг үйлдэх юм уу ярих үед диавол үргэлж оролцохоор хичээдэг ч Бурхан үүнийг огт анзаардаггүй. Диаволыг дурдмагц Бурханы уур хилэн намжаахын аргагүйгээр оргилдог; тэд нэг сүнстэй биш учраас ямар ч холбоо байдаггүй, зөвхөн зай завсар, салалт л байдаг. Долоон лацны тухай илчлэлийг дагаад газар дэлхийн байдал үргэлж улам дордож, бүх зүйл өчүүхэн төдий ч хоцролгүйгээр “долоон лацтай мөр зэрэгцэн урагшилдаг”. Бурханы бүхий л үгэнд Бурхан хүмүүсийг мулгуу гэж үздэг атал тэд огтхон ч сэрдэггүй. Илүү өндөр түвшинд хүрч, бүх хүний хүч чадлыг авчрахын тулд, түүнчлэн Бурханы ажлыг оргилдоо хүрэхэд нь дуусгахын тулд Бурхан цуврал асуулт асууж, хүмүүсийн гэдсийг хийлж байгаа мэт байдаг ба тийнхүү бүх хүнийг дүүргэдэг. Энэ хүмүүст ямар ч бодит биеийн хэмжээ байхгүй учраас бодит нөхцөл байдалд тулгуурлаад хийгээр дүүргүүлсэн хүмүүс бол стандартад нийцэх бараа, харин тэгээгүй нь хэрэггүй хог хаягдал юм. Энэ бол хүнд тавих Бурханы шаардлага бөгөөд Түүний ярьдаг арга барилын зорилго билээ. Ялангуяа Бурханыг “Газар дээр байхдаа Би тэнгэрт байдгаасаа өөр байдаг гэж үү? Тэнгэрт байхдаа Би газарт буун ирж чадахгүй гэж үү? Газарт байхдаа Би тэнгэрт хүрэх үнэ цэнгүй байдаг юм гэж үү?”

хэмээн хэлэх үед эдгээр асуулт нь хүмүүст Бурханыг улам тодорхой мэдүүлдэг. Бурханы үгээс Бурханы яаруу хүсэл харагддаг; хүмүүс үүнд хүрэх чадваргүй бөгөөд Бурхан удаа дараа болзол нэмж, улмаар газар дээрх тэнгэрлэг Бурханыг мэдэж, мөн тэнгэрт байдаг боловч газар дээр амьдардаг Бурханыг мэдэхийг бүх хүнд сануулдаг.

Бурханы үгээс хүний байр байдлыг харж болно: “Бүх хүн төрөлхтөн Миний үгэнд хичээл зүтгэл гаргаж, гадаад байдлыг минь өөрсдөө шинжилдэг ч бүгд л бүтэлгүйтэж, хичээл чармайлт нь ямар ч үр дүнд хүрдэггүй, харин ч Миний үгэнд цохигдоод дахин босож зүрхэлдэггүй.” Бурханы уй гашууг хэн ойлгож чадах билээ? Бурханы зүрх сэтгэлийг хэн тайвшруулж чадах билээ? Бурханы шаардсан зүйл дээр хэн Бурханы зүрх сэтгэлд нийцдэг билээ? Хүмүүс ямар ч үр дүнгүй байх үедээ өөрсдийгөө үгүйсгэж, Бурханы зохион байгуулалтад үнэхээр захирагддаг. Аажмаар үнэн сэтгэлээ харуулангаа тэд дор бүрнээ төрлийнхөө дагуу ангилагддаг бөгөөд тиймээс тэнгэрэлчийн мөн чанар бол Бурханд цэвэр дуулгавартай байдал юм гэдгийг харж болно. Иймээс Бурхан: “Хүмүүсийн анхдагч төрх ил болж” гэж хэлсэн. Бурханы ажил энэ алхамд хүрэх үед бүгд дууссан байх болно. Бурхан Өөрийн хөвгүүд, ардуудад үлгэр жишээ болж байсан талаараа юу ч хэлдэггүй, харин бүх хүний анхдагч төрхийг харуулахад анхаарлаа төвлөрүүлдэг мэт харагддаг. Та нар эдгээр үгийн жинхэнэ утгыг ойлгож байна уу?

27-Р БҮЛЭГ

Өнөөдөр Бурханы үг оргилдоо хүрсэн, өөрөөр хэлбэл, шүүлтийн эриний хоёр дахь хэсэг оргилдоо хүрсэн. Гэхдээ энэ бол хамгийн өндөр оргил нь биш. Энэ удаа Бурханы дууны өнгө өөрчлөгдсөн—энэ нь тохуурхсан ч биш, хошигносон ч биш байгаа бөгөөд цээрлүүлдэг ч үгүй, эсвэл загнадаг ч үгүй; Бурхан үгийнхээ өнгө аясыг зөөлрүүлсэн. Одоо Бурхан хүнтэй хамт “хуучин мэдрэмжээ дурсаж” эхэлдэг. Бурхан шүүлтийн эриний ажлыг үргэлжлүүлэхийн сацуу ажлын дараагийн хэсгийн замыг нээж байгаа, ингэснээр Түүний ажлын бүх хэсэг өөр хоорондоо сүлжилддэг. Нэг талаар Тэр хүний “өөрчлөгдөшгүй байдал ба хуучнаа давтах явдлын” тухай ярьдаг, нөгөө талаар Тэр “хүнээс хагацаж, дараа нь эргэн нийлэхийн баяр хөөр, уйтгар гуниг”-ийн тухай ярьдаг—эдгээр нь бүгд хүмүүсийн зүрх сэтгэл дэх хариу үйлдлийг өдөөж, хүний хамгийн цэвдэг сэтгэлийг хүртэл хөдөлгөдөг. Эдгээр үгийг хэлэх Бурханы зорилго нь үндсэндээ, бүр эцэст нь бүх хүнийг Бурханы өмнө чимээгүйхэн унагах явдал бөгөөд дараа нь “Би Өөрийн үйлдлийг харуулж, бүтэлгүйтлээр нь дамжуулан хүн бүрд Өөрийгөө мэдүүлдэг.” Энэ үед Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг тэр чигтээ өнгөц хэвээр үлддэг; энэ нь жинхэнэ мэдлэг биш. Хэдий тэд чадах чинээгээрээ шаргуу оролдсон ч Бурханы хүслийг биелүүлэх чадваргүй. Өнөөдөр Бурханы үг дээд цэгтээ хүрсэн боловч хүмүүс эхэн үеийн үе

шатанд үлддэг тул одоогийн айлдваруудад орох чадваргүй байдаг—энэ нь Бурхан хүн хоёр өдөр шөнө шиг ялгаатай гэдгийг харуулдаг. Энэ харьцуулалтад үндэслэвэл, Бурханы үг төгсгөлдөө очих үед хүмүүс Бурханы хамгийн доод стандартад л хүрэх чадвартай байх болно. Агуу улаан лууны бүрэн завхруулсан энэ хүмүүс дээр Бурханы ажилладаг арга барил энэ бөгөөд хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд Бурхан тийнхүү ажиллах ёстой юм. Чуулганы хүмүүс Бурханы үгэнд арай илүү анхаарал хандуулдаг боловч Бурханы санаа зорилго бол тэд Өөрийнх нь үгээс Бурханыг мэдэх явдал—энд ялгаа байгаа бус уу? Гэвч, одоогийн энэ байдалд, Бурхан хүний сул талыг анхаарахаа болиод, хүмүүс үгийг нь хүлээн зөвшөөрөх эсэхээс үл хамааран үргэлжлүүлэн ярьдаг. Түүний хүслийн дагуу бол Түүний үг төгсөх үе нь газар дээрх Түүний ажил дуусах үе байх болно. Гэхдээ одоо үеийн ажил өнгөрсөнтэй адилгүй. Бурханы айлдварууд төгсгөлдөө очих үед хэн ч мэдэхгүй; Бурханы ажил төгсгөлдөө очих үед хэн ч мэдэхгүй; Бурханы хэлбэр өөрчлөгдөх үед хэн ч мэдэхгүй. Энэ нь Бурханы мэргэн ухаан юм. Сатаны аливаа буруушаалт болон дайсагнагч хүчний ямар нэгэн хөндлөнгийн оролцооноос зайлсхийхийн тулд Бурхан хэнд ч мэдэгдэхгүйгээр ажилладаг бөгөөд энэ удаа газар дээрх хүмүүсийн дунд ямар ч хариу үйлдэл байдаггүй. Хэдийгээр Бурханы дүр өөрчлөгдөх тэмдгүүдийг нэгэнтээ ярьж байсан ч хэн ч үүнийг ухамсарлаж чаддаггүй, учир нь хүн үүнийг мартсан ба үүнд ямар ч анхаарал хандуулдаггүй. Дотор ба гадна талын аль алины дайралтуудаас болж—гадаад ертөнцийн гай гамшиг болон Бурханы үгийн шатаалт, цэвэрлэгээнээс болж—хүмүүс Бурханы төлөө шаргуу хөдөлмөрлөх хүсэлгүй болсон, учир нь тэд хувийн хэрэг явдалдаа хэтэрхий завгүй байдаг. Бүх хүн өнгөрсөн үеийн мэдлэг болон эрэл хайгуулыг үгүйсгэх хэмжээнд хүрэх үедээ, мөн бүх хүн өөрсдийгөө тодорхой харах үедээ бүтэлгүйтэж, өөрөө өөрийнхөө зүрх сэтгэлд зай эзлэхээ болино. Зөвхөн тэр үед л хүмүүс Бурханы үгийг чин сэтгэлээсээ хүсэн мөрөөснө, зөвхөн тэр үед л Бурханы үг тэдний зүрх сэтгэлд үнэхээр зай эзлэх ба тэр үед л эдгээр үг оршин тогтнолынх нь эх сурвалж болно—энэ мөчид Бурханы хүсэл биелнэ. Гэхдээ өнөөгийн хүмүүс тэр цэгт хүртэл мөн ч өдий байна. Зарим нь арай ядан ямхын төдий л хөдөлсөн, тиймээс Бурхан үүнийг “хуучнаа давтах явдал” гэж хэлдэг.

Бурханы бүх үг олон асуулт агуулдаг. Яагаад Бурхан тийм асуултууд асуусаар байдаг вэ? “Хүмүүс яагаад гэмшиж, дахин төрж чаддаггүй юм бэ? Тэд шавар шавхайгүй газар амьдрахын оронд намаг балчиг дотор амьдрахыг яагаад үргэлж хүсдэг юм бэ? …” Урьд нь Бурхан аливааг шууд заан үзүүлэх буюу шууд илчлэх арга барилаар ажилласан. Гэхдээ хүмүүс асар их шаналал амссаны дараа Бурхан тийм маягаар шууд ярихаа больсон юм. Хүмүүс эдгээр асуултаас өөрсдийнхөө дутагдлыг харахын сацуу хэрэгжүүлэх замыг ухаардаг. Хүмүүс бүгд бэлэн байгаа зүйлийг идэх дуртай байдаг учраас Бурхан тэдний шаардлагад тохируулан үг хэлж, тэднийг тунгаан бодог гэсэндээ эргэцүүлэн бодох сэдвүүдийг өгдөг. Энэ бол Бурханы асуултуудын ач холбогдлын нэг тал юм. Мэдээж, энэ нь Түүний зарим нэг асуултын

ач холбогдол биш, жишээ нь: Би тэдэнд зохисгүй хандсан юм гэж үү? Би тэднийг буруу зүг рүү чиглүүлсэн юм гэж үү? Би тэднийг там руу хөтөлж байгаа юм гэж үү? Иймэрхүү асуултууд нь хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнд шигдсэн үзлийг харуулдаг. Хэдийгээр ам нь хэлэхгүй байгаа ч ихэнх хүмүүсийн зүрх сэтгэл дотор эргэлзээ байдаг бөгөөд Бурханы үг өөрсдийг нь огт гавьяагүй хүмүүс болгон дүрсэлдэг гэж тэд итгэдэг. Мэдээжийн хэрэг, ийм хүмүүс өөрсдийгөө мэддэггүй боловч эцэстээ Бурханы үгэнд ялагдсанаа хүлээн зөвшөөрнө—энэ бол зайлшгүй. Эдгээр асуултын дараа Бурхан бас “Би хүний гэр бүлийг бүү хэл, бүх үндэстнийг бут цохихоор зорьдог” гэж хэлсэн байдаг. Хүмүүс Бурханы нэрийг хүлээн зөвшөөрөхөд үүний үр дүнд бүх үндэстэн ганхаж, хүмүүсийн сэтгэхүй аажмаар өөрчлөгдөж, гэр бүлүүдэд, эцэг хүү, эх охин, эхнэр нөхрийн хоорондох харилцаа оршин байхаа болино. Түүнчлэн, гэр бүлүүд дэх хүмүүс хоорондын харилцаа улам бүр хол хөндий болно; тэд агуу гэр бүлд нэгдэж, бараг бүх гэр бүлийн тогтсон заншил алдагдана. Үүний улмаас хүмүүсийн зүрх сэтгэл дэх “гэр бүл”-ийн тухай ойлголт улам бүр бүрхэг болно.

Яагаад Бурханы өнөөдрийн үгийн тун ихээхэн нь хүмүүстэй хамт “хуучин мэдрэмжээ дурсахад” зориулагдсан бэ? Мэдээжийн хэрэг, энэ нь бас тодорхой үр дүнд хүрэхийн төлөө байдаг бөгөөд Бурханы зүрх сэтгэл зовнилоор дүүрснийг үүнээс харж болно. Бурхан: “Намайг гуниглах үед хэн чин сэтгэлээсээ тайтгаруулж чадах билээ?” гэж хэлсэн байдаг. Зүрх сэтгэл нь уй гашууд автсан учраас Бурхан эдгээр үгийг хэлсэн. Хүмүүс Бурханы хүсэлд бүх анхаарлаа хандуулах чадваргүй, үргэлж замбараагүй байж, өөрсдийгөө хянаж чаддаггүй, хүссэнээ л хийдэг; тэд дэндүү дорд агаад өөрсдийгөө үргэлж уучилж, Бурханы хүслийг хайхардаггүй. Гэхдээ хүмүүс өнөөдрийг хүртэл Сатанаар завхруулагдсан бөгөөд өөрсдийгөө чөлөөлөх чадваргүй байдаг учраас Бурхан: “Тэд яаж ховдог чонын амнаас зугтаж чадах билээ? Тэд үүний заналхийлэл, уруу таталтаас өөрсдийгөө чөлөөлж яаж чадах билээ?” гэж хэлсэн юм. Хүмүүс махан биед буюу ховдог чонын аманд амьдардаг. Үүнээс болоод, мөн хүмүүст ямар ч өөрийн ухамсар байдаггүй, үргэлж өөрсдийгөө өөгшүүлж, садар самуунд автдаг учраас Бурхан өөрийн эрхгүй түүгшдэг. Бурхан хүмүүст ингэж сануулах тусам, тэдний сэтгэл улам дээрдэж, Бурхантай холбогдохыг улам их хүсдэг. Тэр үед л хүн Бурхан хоёр ямар ч хагацал, зай завсаргүйгээр бие биетэйгээ эв зохицолтойгоор харилцана. Өнөөдөр бүх хүн төрөлхтөн Бурханы өдөр ирэхийг хүлээдэг тул хүн төрөлхтөн хэзээ ч урагшлаагүй. Гэсэн ч Бурхан: “Зөвт байдлын Нар гарч ирэх үедээ Зүүн зүгийг гэрэлтүүлж, дараа нь орчлон ертөнцийг тэр аяар нь гэрэлтүүлэн, хүн бүрд хүрнэ” гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийн хэлбэрийг өөрчлөх үедээ Зүүн зүгийг эхлээд гэрэлтүүлж, Зүүн зүгийн үндэстнийг эхлээд солино, үүний дараа үлдсэн улс орнуудыг өмнө зүгээс хойд зүгт хүртэл шинэчилнэ. Энэ бол дараалал бөгөөд бүгд Бурханы үгийн дагуу байх болно. Энэ үе шат дуусмагц бүх хүн харна. Энэ дарааллын дагуу Бурхан ажилладаг. Энэ өдрийг харах үедээ хүмүүс хөөрөн баярлана. Энэ өдөр тийм ч холгүй байгааг Бурханы яаралтай санаа зорилгоос харж болно.

Өнөөдөр энд хэлсэн үгийн хоёр дахь болон гурав дахь хэсэг нь Бурханыг хайрладаг бүх хүний шаналлын нулимсыг урсгадаг. Тэдний зүрх сэтгэлийг нэн даруй сүүдэр нөмөрч, энэ үеэс эхлэн Бурханы зүрх сэтгэлээс болж бүх хүн асар их уйтгар гунигт автдаг. Бурханыг газар дээрх ажлаа дуусгах хүртэл тэд тайвшралыг мэдрэхгүй. Энэ бол ерөнхий чиг хандлага. “Миний зүрх сэтгэл дотор уур хилэн нэмэгдэж, дараа нь уйтгар гунигийн мэдрэмжээр бялхдаг. Миний нүд хүмүүсийн үйл хэрэг, үг, үйлдэл нэг бүрийг нь бохир бузар хэмээн харах үед уур хилэн минь буцалж, зүрх сэтгэл минь хүний ертөнцийн шударга бус байдлыг асар их мэдэрдэг ба энэ нь Намайг улам их гуниглуулдаг; Би хүний махан биеийг даруй төгсгөхийг тэсэн ядан хүлээдэг. Хүн махан биед байхдаа яагаад өөрийгөө ариусгаж чаддаггүйг, хүн махан биед байхдаа өөрийгөө яагаад хайрлаж чаддаггүйг Би мэдэхгүй. Махан биеийн ‘чиг үүрэг’ асар их юм гэж үү?” Өнөөдрийн үгэндээ Бурхан, Өөрийнх нь зүрх сэтгэлд буй түгшүүрийг юу ч үлдээлгүйгээр бүгдийг нь хүнд илэн далангүй илчилсэн. Гурав дахь тэнгэрийн тэнгэрэлчүүд Өөрт нь зориулан хөгжим тоглох үед Бурхан газар дээрх хүмүүсийг хүсэн эрмэлзсээр байдаг ба үүнээс болоод Тэр: “Тэнгэрэлчүүд Намайг магтан хөгжим тоглох үедээ хүнийг өрөвдөх сэтгэлийг минь өөрийн эрхгүй өдөөдөг. Миний зүрх сэтгэл даруй гунигаар дүүрч, энэхүү зовлонт сэтгэл хөдлөлөөс Өөрийгөө салгах боломжгүй байдаг” гэсэн юм. Энэ шалтгааны улмаас Бурхан: “Би хүний ертөнцийн шударга бус явдлыг засна. Би дэлхий даяар Өөрийнхөө ажлыг гардан хийнэ, ардуудыг минь дахин хорлохыг Сатанд зөвшөөрөхгүй, хүссэн бүхнээ дахин хийхийг дайснууддаа зөвшөөрөхгүй. Би газар дээр Хаан болж, Өөрийн сэнтийг тэнд шилжүүлээд, бүх дайснаа газар унаган мөргүүлж, тэдний нүглийг Өөрийн өмнө улайлгана” хэмээх үгийг хэлсэн билээ. Уйтгар гунигаасаа болоод Бурхан диаволыг улам их үзэн яддаг, тиймээс Тэр диаволууд яаж төгсөхийг олон нийтэд урьдчилан илчилдэг. Энэ бол Бурханы ажил билээ. Бурхан бүх хүнтэй дахин нэгдэж, хуучин эрин үеийг төгсгөхийг үргэлж хүссээр ирсэн. Орчлон ертөнц даяарх бүх хүн хөдөлж эхэлж байна—өөрөөр хэлбэл, сансар огторгуй дахь бүх хүн Бурханы удирдамжид орж байна. Үүний үр дүнд, тэдний бодол хаадынхаа эсрэг тэрсэлж эхэлсэн. Тун удалгүй дэлхий ертөнцийн хүмүүс эмх замбараагүй байдал үүсгэж, бүх улс орны тэргүүнүүд зүг бүхэн рүү дүрвэн, эцэстээ ард түмэн нь тэднийг зандалчны хавтан руу түлхэнэ. Энэ бол диаволын хаадын эцсийн төгсгөл; эцэстээ хэн ч үүнээс зугтаж чадахгүй ба бүгд үүнийг дамжих ёстой. Өнөөдөр “ухаантай” хүмүүс байр сууринаасаа бууж эхэлсэн. Нөхцөл байдал таагүй байгааг хараад тэд энэ боломжийг ашиглан ухарч, гай гамшгийн зовлонгоос зугтдаг. Гэхдээ Би шулуухан хэлье, эцсийн өдрүүдэд Бурханы хийдэг ажил нь үндсэндээ хүнийг гэсгээх гэсгээлт тул энэ хүмүүс яаж ер нь зугтаж чадах юм бэ? Өнөөдөр бол эхний алхам. Нэг л өдөр, орчлон ертөнц дэх бүх зүйл дайны хөлд унана; газар дэлхийн хүмүүс дахин хэзээ ч удирдагчтай байхгүй бөгөөд бүхий л дэлхий ертөнц хэнээр ч удирдуулалгүй, овоолсон элсэн ширхэг шиг байж, хүмүүс өөр хэнийг ч хайхрахгүйгээр өөрсдийнхөө амийг л

анхаарна, учир нь бүх зүйлийг Бурханы гар хянадаг билээ—ийм учраас Бурхан “Бүх хүн Миний хүслийн дагуу янз бүрийн улс орнуудыг хагалан бутаргаж байна” гэж хэлдэг. Бурханы одоо ярьж буй “тэнгэрэлчүүдийн бүрээ” бол тэмдэг—тэдгээр нь хүнд зориулан сэрүүлэг дуугаргаж байгаа бөгөөд бүрээнүүд дахин нэгэнтээ дуугарах үед дэлхийн эцсийн өдөр хүрэлцэн ирсэн байх болно. Тэр үед Бурханы бүхий л гэсгээлт тэр чигтээ газар дээр бууж ирнэ; энэ нь цэвдэг шүүлт, мөн гэсгээлтийн эриний албан ёсны эхлэл байх болно. Израильчуудын дунд, өөр өөр орчинд тэднийг хөтлөх Бурханы дуу хоолой дандаа байх бөгөөд тэнгэрэлчүүд ч бас тэдэнд харагдана. Израильчууд хэдхэн сарын дотор бүрэн төгс болгоулна, тэд агуу улаан лууны хорыг өөрсдөөсөө арилгах алхмыг туулах хэрэггүй учраас тэдний хувьд янз бүрийн удирдамж дор зөв замд орох нь амархан байх болно. Израиль дахь хөгжил хөдөлгөөнөөс бүхий л орчлон ертөнцийн байдлыг харж болох бөгөөд Бурханы ажлын алхмууд хэр хурдан болохыг энэ нь харуулдаг. “Цаг нь ирсэн! Би хүмүүсийн дунд Өөрийн ажлыг өрнүүлж, хүмүүсийн дунд Хаан болон хаанчилна!” Урьд нь Бурхан зөвхөн тэнгэрт хаанчилсан. Өнөөдөр Тэр газар дээр хаанчилдаг; Бурхан бүх эрх мэдлээ буцаан авсан, иймээс бүх хүн төрөлхтөн дахин хэзээ ч хэвийн хүний амьдралаар амьдрахгүй гэж зөгнөгдсөн, учир нь Бурхан тэнгэр, газрыг өөрчлөн шинэчлэх ба ямар ч хүнд хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрөхгүй. Тиймээс Бурхан хүнд “Цаг нь ирсэн!” хэмээн үргэлж сануулдаг. Израильчууд бүгд улс орондоо эргэн очих үед—Израиль улс бүрэн сэргэх үед—Бурханы агуу ажил гүйцэлдэнэ. Нэг л мэдэхэд хүмүүс орчлон ертөнц даяар бослого гаргаж, орчлон ертөнц даяарх улс орнууд тэнгэр дэх одод мэт унана; тэд агшин зуур үнсэн товрог болно. Тэднийг шийдвэрлэснийхээ дараа Бурхан зүрх сэтгэлдээ хайрладаг хаанчлалаа байгуулна.

28-Р БҮЛЭГ

Хүмүүсийн байдал бол Бурханы үгийг бага ойлгох тусмаа Бурханы ажилладаг одоогийн арга барилын талаар илүү их эргэлздэг. Гэхдээ энэ нь Бурханы ажилд ямар ч нөлөө үзүүлдэггүй; Түүний үг тодорхой нэг түвшинд хүрэх үед хүмүүсийн зүрх сэтгэл аяндаа наашлана. Өөрсдийнхөө амьдралд хүн бүхэн Бурханы үгэнд анхаарлаа төвлөрүүлдэг, бас Түүний үгийг эгээрэн хүсэж эхэлдэг бөгөөд Бурханы тасралтгүй илчлэлтийн дүнд тэд өөрсдийгөө жигшиж эхэлдэг. Гэсэн ч Бурхан бас дараах төрлийн үг олныг айлдсан: “Бүх үгийг минь бүрэн ухаарсан үед хүний биеийн хэмжээ хүсэлд минь нийцэж, гуйлт нь хий дэмий, хэрэггүй биш, харин үр өгөөжтэй байдаг; хүн төрөлхтний хуурамч бус, чин сэтгэлийн гуйлтыг Би ерөөдөг.” Үнэндээ, хүмүүс Бурханы үгийг бүрэн ойлгож чаддаггүй, тэд зөвхөн өнгөн хэсгийг л ойлгож чадна. Бурхан тэдэнд зорих зорилго өгөхийн тулд, мөн тэдэнд Бурхан аливаа зүйлийг хөнгөмсөг хийдэггүй, харин Өөрийнхөө ажлыг нухацтай үздэг

гэдгийг мэдрүүлэхийн тулд л эдгээр үгийг ашигладаг; тэд зөвхөн тэр үед л эрэлхийлэх итгэлтэй болно. Бүх хүн Бурханы хүслийн төлөө биш, зөвхөн өөрсдийнхөө төлөө гуйдаг боловч Бурхан хувирамтгай биш учраас Түүний үг үргэлж хүний уг чанар луу чиглэсээр ирсэн юм. Хэдийгээр өнөөдөр ихэнх хүмүүс гуйдаг ч чин сэтгэлээсээ биш—энэ нь зүгээр л худал дүр байдаг. Бүх хүний байгаа байдал нь, “тэд амыг минь элбэг дэлбэгийн ундарга гэж тооцдог. Бүх хүн Миний амнаас ямар нэгэн зүйл олж авахыг хүсдэг. Төрийн нууц ч юм уу, тэнгэрийн оньсого, эсвэл сүнсний ертөнцийн орчил, хүн төрөлхтний хүрэх газар гэх мэт зүйлийг бүх хүн хүлээн авах хүсэлтэй”. Сониуч зангаасаа болж хүмүүс бүгдээрээ эдгээр зүйлийг эрж хайхад бэлэн байдаг ба Бурханы үгээс амийн хангалтын юуг ч олж авахыг хүсдэггүй. Тиймээс Бурхан “Хүмүүс хэтэрхий дутуу дулимаг: хүнд ‘нэмэлт шим тэжээл’ шаардлагатайгаас гадна ‘сэтгэлийн дэм’, ‘сүнслэг хангамж’ хэрэгтэй” гэж хэлдэг. Хүмүүст байдаг үзэл нь өнөөдрийн энэ сөрөг байдал руу хөтөлсөн, тэдний махбодын нүд нь хэтэрхий “феодал” болохоор тэдний хэлж, хийж байгаа зүйлд ямар ч эрч хүч байдаггүй, мөн бүх зүйл дээр хааш яаш, хайнга байдаг. Эдгээр нь хүмүүсийн байгаа байдал биш гэж үү? Хүмүүс ингэж бахь байдгаараа явахын оронд яаравчилж, үүнийгээ засах хэрэгтэй биш үү? Ирээдүйг мэдэх нь хүнд ямар ач тустай юм бэ? Яагаад Бурханы зарим үгсийг уншсаны дараа хүмүүс хариу үйлдэл үзүүлдэг боловч Түүний үгийн үлдсэн хэсэг нь ямар ч үр нөлөөгүй байдаг юм бэ? Жишээлбэл, Бурханыг “Илүү сайн үр дүнд хүрч, тэднийг эрүүл энх болгож, эдгээсний минь ачаар тэд хэвийн байдалдаа эргэн орно байх гэсэндээ Би хүний өвчнийг анагаадаг” хэмээхэд эдгээр үг хүмүүст яагаад нөлөөлдөггүй юм бэ? Бурханы хийсэн бүхэн хүний хүрэх ёстой зүйл байгаагүй юу? Бурханд хийх ажил байдаг—яагаад хүмүүс алхах замгүй байдаг вэ? Энэ нь Бурханд харшилж байгаа биш үү? Үнэндээ, хүмүүсийн хийх учиртай ажил их бий—жишээлбэл, “Агуу улаан лууг та нар үнэхээр үзэн яддаг гэж үү?” хэмээх үгэн дэх агуу улаан лууг тэд хэр зэрэг мэдэх вэ? “Яагаад Би та нараас ийм олон удаа асуув?” гэж Бурхан хэлсэн нь хүмүүс агуу улаан лууны уг чанарын талаар бас л мэддэггүй ба илүү гүнзгий ойлгож чадахгүй хэвээр үлдсэнийг харуулдаг. Энэ нь хүний хийх учиртай яг тэр ажил биш гэж үү? Хүнд хийх ажил байхгүй гэж хэлж яаж болох юм бэ? Хэрвээ тийм байсан бол Бурхан бие махбодтой болохын ач холбогдол юу байсан юм бэ? Бурхан хэлбэрдэхийн төлөө хайнга, хааш яаш ажиллаж байна уу? Агуу улаан лууг ийм байдлаар ялж чадах уу?

Бурхан, “Би аль хэдийн эхэллээ, агуу улаан луу орогнодог газарт Би гэсгээлтийн ажлынхаа эхний алхмыг эхлүүлнэ” гэж хэлдэг. Эдгээр үг бурханлаг чанарын ажилд чиглэсэн; өнөөдрийн хүмүүс урьдчилаад аль хэдийн гэсгээлтэд орсон бөгөөд тиймээс Бурхан, энэ бол Өөрийн ажлын эхний алхам гэж хэлдэг. Хүмүүст гай гамшгийн гэсгээлтийг биш, харин үгийн гэсгээлт амсуулж байна. Учир нь, Бурханы үгийн өнгө аяс өөрчлөгдөхөд хүмүүс бүр мунхаг болдог ба түүний дараа бүгд гэсгээлтэд ордог. Гэсгээлт туулаад “та нар үүргээ албан ёсоор

гүйцэтгэж, газар даяар Намайг албан ёсоор үүрдийн үүрд магтана!” Энэ бол Бурханы ажлын алхам—энэ нь Түүний төлөвлөгөө. Түүнээс гадна, Бурханы энэ хүмүүс агуу улаан лууг гэсгээж буй арга барилыг биечлэн харах болохоор гамшиг тэдний гадуур, тэднийг тойрон буй ертөнцөд албан ёсоор эхэлнэ. Энэ нь хүмүүсийг авардаг Бурханы арга барилуудын нэг юм. Дотоод талдаа тэд гэсгээгддэг ба гадна талаас нь гамшиг нөмөрдөг—өөрөөр хэлбэл, Бурханы үг биелэгддэг. Тиймээс хүмүүс гамшгийн оронд гэсгээлт туулахыг илүүд үзэх бөгөөд үүний дүнд үлддэг. Нэг талаар, энэ бол Бурханы ажлын ирсэн цэг; нөгөө талаар, ингэснээр бүх хүн Бурханы зан чанарыг мэдэж чадах юм. Тиймээс Бурхан, “Агуу улаан луу гэсгээгдсэн цагт ардууд минь Намайг эдэлдэг. Агуу улаан лууны эсрэг хүмүүсийг нь босгож, бослого хийлгэх нь Миний төлөвлөгөө бөгөөд ардуудаа төгс болгодог Миний арга, мөн бүх ард маань амиа өсгөх сайхан боломж энэ юм” гэж хэлдэг. Бурхан эдгээр үгийг хэлсэн боловч тэдгээр нь яагаад хүмүүсийн анхаарлыг татдаггүй вэ?

Улс орнууд маш эмх замбараагүй байдалтай байна, учир нь Бурханы саваа газар дээр үүргээ биелүүлж эхэлсэн. Газар дэлхийн нөхцөл байдлаас Бурханы ажлыг харж болно. Бурханыг “ус шуугьж, уул нурж, их мөрөн сарнина” гэж хэлэхэд энэ нь сабааны газар дээрх анхны ажил бөгөөд үүний үр дүнд “Газар дээрх бүх айл өрх тарж бутран, дэлхий дээрх бүх улс үндэстэн задран хуваагдана; эхнэр нөхөр хоёр дахин уулзах өдөргүй болж, ээж хүү хоёр дахин үл уулзаж, эцэг охин хоёрын уулзалт дахин хэзээ ч үл тохионо. Газар дэлхий дээр байсан бүхнийг Би бут цохино”. Газар дээрх айлуудын ерөнхий төлөв ийм болно. Мэдээж, бүгдийнх нь байдал тийм байж болохгүй боловч ихэнхийн байдал энэ юм. Нөгөө талаар, энэ нь энэхүү урсгалын хүмүүсийн ирээдүйд туулж мэдрэх нөхцөл байдлыг хэлж байна. Тэд үгийн гэсгээлтийг туулж, үл итгэгчид гамшигт өртсөний дараа газар дээрх хүмүүсийн дунд гэр бүлийн харилцаа байхаа болино гэдгийг энэ зөгнөдөг; тэд бүгд Синимийн хүмүүс байх бөгөөд бүгд Бурханы хаанчлалд үнэнч байх болно. Тиймээс, эхнэр нөхөр хоёр дахин уулзах өдөргүй болж, ээж хүү хоёр дахин үл уулзаж, эцэг охин хоёрын уулзалт дахин хэзээ ч үл тохионо. Иймд газар дээрх хүмүүсийн гэр бүл салж хагацан, бутарч задрах бөгөөд энэ нь хүний дотор хийх Бурханы сүүлчийн ажил байх болно. Бурхан энэхүү ажлыг орчлон ертөнц даяар түгээх учраас “сэтгэл хөдлөл” хэмээх үгийг хүмүүст тодруулах боломжийг ашигладаг, тийнхүү Бурханы хүсэл бол бүх хүний гэр бүлийг салгах явдал гэдгийг ойлгох боломжийг тэдэнд олгож, хүн төрөлхтний дундах гэр бүлийн бүх маргааныг шийдвэрлэхийн тулд Бурхан гэсгээлт ашигладаг гэдгийг харуулдаг. Эс бөгөөс газар дээрх Бурханы ажлын сүүлчийн хэсгийг төгсгөх ямар ч арга байхгүй байх юм. Бурханы үгийн сүүлчийн хэсэг нь хүн төрөлхтний хамгийн том сул талыг ил болгодог—тэд бүгд сэтгэл хөдлөлд амьдардаг—иймээс Бурхан тэдний нэгээс нь ч зайлсхийдэггүй ба бүх хүн төрөлхтний зүрх сэтгэлд нуугдсан нууцуудыг илчилдэг. Сэтгэл хөдлөлөөсөө салах хүмүүст яагаад тийм хэцүү байдаг юм бэ? Тэгэх нь мөс

чанарын стандартыг давна гэж үү? Мөс чанар нь Бурханы хүслийг биелүүлж чадах уу? Гай тотгорыг туулахад сэтгэл хөдлөл хүмүүст тусалж чадах уу? Бурханы үзэхэд, сэтгэл хөдлөл бол Түүний дайсан—үүнийг Бурханы үгэнд тодорхой өгүүлээгүй гэж үү?

29-Р БҮЛЭГ

Хүмүүсийн хийсэн ажлаас зарим нь Бурханы шууд зааврааp гүйцэтгэгддэг боловч Бурхан тодорхой заавар өгдөггүй хэсэг ч бас байдаг бөгөөд Бурханы хийсэн зүйл өнөөдөр хараахан бүрэн илчлэгдээгүй гэдгийг хангалттай харуулдаг—өөрөөр хэлбэл, ихэнх нь нууцлаг хэвээр үлдээд, хараахан ил тод болоогүй. Гэхдээ зарим зүйлийг ил болгох хэрэгтэй байдаг, харин зарим нь хүмүүсийг будилуулж, төөрөгдүүлж орхих хэрэгтэй байдаг; энэ нь Бурханы ажилд шаардагддаг зүйл юм. Жишээлбэл, Бурхан тэнгэрээс хүмүүсийн дунд ирсэн явдал—Тэр хэрхэн ирсэн, ямар хоромд ирсэн, эсвэл тэнгэр, газар, бүх зүйл өөрчлөгдсөн эсэх—хүмүүсийг будилуулахад эдгээр зүйл шаардлагатай. Энэ нь бас бодит нөхцөл байдалд үндэслэдэг, учир нь хүний махан бие өөрөө сүнслэг ертөнцөд шууд орох чадваргүй. Тиймээс Бурхан тэнгэрээс газарт яаж ирснээ тодорхой хэлсэн ч гэсэн, эсвэл Түүнийг “Бүх зүйл дахин амилсан өдөр Би хүмүүсийн дунд ирсэн ба Би түүнтэй хамт гайхалтай өдөр, шөнүүдийг өнгөрүүлсэн” гэж хэлэх үед ч гэсэн, ийм үгс нь хэн нэгэн хүн модны их биетэй ярьж байгаатай адил—өчүүхэн төдий ч хариу үйлдэл байдаггүй, учир нь хүмүүс Бурханы ажлын алхмуудын талаар мэддэггүй. Тэд үнэхээр мэддэг байлаа ч гэсэн, Бурхан тэнгэрээс газар луу үлгэрийн дагина шиг нисэн ирээд, хүмүүсийн дунд төрсөн гэж итгэдэг. Энэ нь хүний бодлоор хүрэх боломжтой зүйл юм. Яагаад гэвэл, Бурханы мөн чанарыг ойлгож чаддаггүй, сүнслэг ертөнцийн бодит байдлыг ойлгож чаддаггүй нь хүний мөн чанар билээ. Өөрсдийн дан ганц мөн чанарааpаа хүмүүс бусдад үлгэр жишээ болон үйлдэх чадваргүй байдаг, учир нь хүмүүс төрөлхөөсөө өөр биш, харин адилхан. Тиймээс бусдын дагах үлгэр жишээ болохыг, эсвэл үлгэр дуурайл үзүүлэхийг хүмүүсээс шаардах нь хөөс болдог, уснаас савсаж буй уур болдог. Харин Бурханыг “Надад юу байгаа, Би юу болох талаар зарим нэг мэдлэг олж авах” гэж хэлэх үед эдгээр үг нь ердөө махбодоор Бурханы хийдэг ажлын илрэлийг л хэлж байгаа; өөрөөр хэлбэл, тэдгээр нь Бурханы жинхэнэ нүүр царай буюу бурханлаг чанар луу чиглэдэг, энэ нь үндсэндээ Түүний бурханлаг зан чанарыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан яагаад ийм маягаар ажилладаг, Бурханы үгээр ямар зүйл гүйцэлдэх, Бурхан газар дээр юунд хүрэхийг хүсдэг, хүмүүсийн дундаас юу олж авахыг хүсдэг, Бурханы ярьдаг арга барил, хүнд хандах Бурханы хандлага юу болох гэх мэт зүйлсийг ойлгохыг хүмүүсээс шаарддаг. Хүнд бардамнаад байх зүйл юу ч байхгүй—өөрөөр хэлбэл, бусдын дагах үлгэр жишээг тогтоож чадах юу ч байхгүй.

Чухамдаа махбод дахь Бурханы хэвийн байдлаас болоод, тэнгэр дэх Бурхан болон тэнгэр дэх Бурханаас төрсөн гэж санагдахааргүй махбод дахь Бурханы ялгаанаас болоод Бурхан: “Би хүмүүсийн дунд олон жилийг өнгөрүүлсэн боловч хүн дандаа тоомжиргүй хэвээр байж, Намайг ер мэдээгүй” гэж хэлсэн юм. Бурхан бас, “Миний мөр орчлон ертөнц болон газар дэлхийн зах хязгаар хүртэл явах үед хүн өөрийгөө эргэцүүлж эхлэх ба бүх хүн Над руу ирж, Миний өмнө мэхийн ёсолж, Намайг шүтэн мөргөнө. Энэ нь Би алдрыг олж авах өдөр, Миний эргэн ирсэн өдөр, мөн Миний явах өдөр байх болно” гэсэн. Энэ нь л Бурханы жинхэнэ нүүр царай хүнд харагдах өдөр юм. Гэсэн ч үүнээс болоод Бурхан Өөрийн ажлыг хойшлуулдаггүй, Тэр зүгээр л хийх учиртай ажлаа хийдэг. Шүүх үедээ Тэрээр махбод дахь Бурханд хандах хандлагынх нь дагуу хүмүүсийг ялладаг. Энэ нь, тус хугацаан дахь Бурханы айлдваруудын үндсэн уялдаа холбооны нэг юм. Жишээлбэл, Бурхан: “Би бүх орчлон даяар Өөрийн удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийг албан ёсоор эхлүүлчихсэн. Анхаарал болгоомжгүй хэнд ч энэ мөчөөс эхлэн хайр найргүй гэсгээлт оногдож болзошгүй” гэж хэлсэн. Энэ нь Бурханы төлөвлөгөөний агуулга бөгөөд этгээд сонин ч биш, хачин ч биш, харин Түүний ажлын алхмуудын бүх хэсэг юм. Энэ хооронд, хилийн чанадад байгаа Бурханы ардууд болон хөвгүүд чуулганд хийдэг бүхнийхээ үндсэн дээр Бурханаар шүүгддэг тул Бурхан: “Намайг ажиллаж байхад тэнгэрэлчүүд бүгд Надтай хамт шийдвэрлэх тулаан эхлүүлж, сүүлчийн шатанд Миний хүслийг биелүүлэхээр шийддэг, ингээд газар дээрх хүмүүс тэнгэрэлчүүдийн адилаар Миний өмнө буулт хийж, Намайг эсэргүүцэх ямар ч хүсэлгүй болж, Миний эсрэг тэрслэх юу ч хийдэггүй. Эдгээр нь орчлон ертөнц даяарх Миний ажлын чиг хандлага билээ” гэсэн. Энэ нь газар дэлхий даяар Бурханы гүйцэтгэдэг ажилд буй ялгаа юм; Тэрээр хэнд чиглэж буйгаас хамааран өөр өөр арга хэмжээ авдаг. Өнөөдөр чуулганы хүмүүс бүгдээрээ хүсэн тэмүүлсэн зүрх сэтгэлтэй байдаг бөгөөд тэд Бурханы үгийг идэж, ууж эхэлсэн—энэ нь Бурханы ажил төгсгөлдөө ойртож буйг хангалттай харуулдаг. Тэнгэрээс доош харах нь хатаж гандсан мөчир, унасан навчис, намрын салхинд хийссэн алтан хэмэрлэгийн уйтгарт дүр зургийг дахин нэгэнтээ харахтай адилхан. Хүмүүсийн дунд ертөнцийн төгсгөл тохиох гэж буй мэт, бүгд эзгүйрч хоосрох гэж буй мэт санагддаг. Магадгүй Сүнсний мэдрэмтгий чанараас болоод зүрх сэтгэлд аз жаргалгүй байдлын мэдрэмж, өчүүхэн жаахан тайван амгалан байдлын хамтаар үргэлж байдаг ч бага зэргийн уй гашуутай холилддог. Энэ нь, “хүмүүс сэрж, газар дээрх бүх зүйл эмх журамдаа орж, газар дэлхийн оршин байх өдрүүд үгүй болж байна, учир нь Би ирчихсэн!” хэмээх Бурханы үгийн дүрслэл байж магадгүй. Хүмүүс эдгээр үгийг сонссоныхоо дараа зарим талаар сөрөг болж магадгүй, Бурханы ажилд бага зэрэг урам хугарч болзошгүй, эсвэл өөрсдийнхөө сүнсний мэдрэмжид илүү их анхаарч магадгүй. Гэхдээ газар дээрх Өөрийн ажлыг дуусгахаас өмнө Бурхан, хүмүүст тийм буруу ойлголт өгөхүйц тэнэг байж таарахгүй. Хэрвээ чамд үнэхээр тийм мэдрэмж байгаа бол чи өөрийнхөө мэдрэмжид хэтэрхий их анхаарал

хандуулж байгаа ба чи бол мэдрэмжийнхээ дагуу хийдэг, Бурханыг хайрладаггүй хүн юм гэдгийг энэ нь харуулдаг; тийм хүмүүс ер бусын зүйлд хэтэрхий их анхаардаг бөгөөд Бурханыг огтхон ч анхаардаггүй гэдгийг энэ нь харуулдаг. Бурханы гарын улмаас, хүмүүс булталхаар хэчнээн их оролдох нь хамаагүй энэ нөхцөл байдлаас зугтаж чаддаггүй. Хэн Бурханы гараас зугтаж чадах юм бэ? Чиний байр суурь, нөхцөл байдал хэзээ Бурханаар зохицуулагддаггүй байсан юм бэ? Зовсон ч бай, эсвэл ерөөгдсөн ч бай, чи яаж Бурханы гараас булталж чадах юм бэ? Энэ бол хүний хэрэг явдал биш, харин тэр чигтээ Бурханы хэрэгцээ юм—үүнээс болж хэн дуулгавартай дагахгүй байж чадах билээ?

“Би Өөрийн ажлыг Харь үндэстнүүдийн дунд түгээхийн тулд гэсгээлт ашиглана, өөрөөр хэлбэл, Би Харь үндэстнүүдийн эсрэг хүч хэрэглэнэ. Мэдээжээр, энэхүү ажил нь сонгогдсон хүмүүсийн дунд явагдах Миний ажилтай зэрэг хийгдэнэ.” Эдгээр үгийг айлдсанаар Бурхан энэ ажлыг орчлон ертөнц даяар эхлүүлдэг. Энэ бол Бурханы ажлын алхам бөгөөд аль хэдийн өдий хүртэл урагшилсан; хэн ч аливааг өөрчилж чадахгүй. Гай гамшиг хүн төрөлхтний нэг хэсгийг шийдвэрлэж, тэднийг дэлхийтэй хамт мөхөхөд хүргэнэ. Орчлон ертөнц албан ёсоор гэсгээгдэх үед Бурхан бүх хүнд албан ёсоор харагддаг. Тэгээд Түүний илрэлтээс болж хүмүүс гэсгээгддэг. Үүнээс гадна Бурхан бас “Би хуйлмал номыг албан ёсоор нээх үе нь орчлон ертөнц даяарх хүмүүс гэсгээгдэх үе, дэлхий дахины хүмүүст шалгалт тулгарах үе” гэж хэлсэн. Үүнээс, долоон лацны агуулга нь гэсгээлтийн агуулга гэдгийг, өөрөөр хэлбэл, долоон лацны дотор гай гамшиг байдаг гэдгийг тодорхой харж болно. Тиймээс өнөөдөр долоон лац хараахан нээгдээгүй байгаа; энд дурдсан “шалгалт” гэдэг нь хүний амсдаг гэсгээлт бөгөөд энэхүү гэсгээлтийн дундаас Бурханы олгосон “сертификатыг” албан ёсоор хүлээн авах бүлэг хүмүүсийг олж авна, тэгээд тэд Бурханы хаанчлалын ардууд болно. Эдгээр нь Бурханы хөвгүүд, ардуудын эх үндэс бөгөөд өнөөдөр тэд хараахан шийдэгдээгүй, ердөө л хожмын туршлагынхаа суурийг тавьж байгаа. Хэрвээ хэн нэгэнд жинхэнэ амь байгаа бол шалгалтуудын үеэр бат зогсож чадна, хэрвээ тэдэнд амь байхгүй бол Бурханы ажил тэдэнд ямар үр нөлөө үзүүлээгүй, тэд булингартай усанд загасчилдаг, Бурханы үгэнд анхаарал хандуулдаггүй гэдгийг энэ нь хангалттай нотолдог. Энэ нь эцсийн өдрүүдийн ажил бөгөөд ажлыг үргэлжлүүлэхийн оронд эрин үеийг төгсгөхийн төлөө байдаг учраас Бурхан: “Өөрөөр хэлбэл, бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөг хүртэл хүмүүсийн туулаагүй амьдрал энэ бөгөөд иймээс Би өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийдэг гэж хэлж байгаа юм” гэсэн бөгөөд Тэр бас “Миний өдөр бүх хүн төрөлхтөнд ойртож байгаа учраас, мөн энэ нь хол юм шиг харагдахгүй, харин яг хүний нүдний өмнө байгаа учраас” гэж хэлсэн. Өнгөрсөн үед Бурхан хэд хэдэн хотыг биечлэн устгасан, гэхдээ тэдгээрийн аль нь ч эцсийн удаа тохиолдох зүйлтэй адилаар сүйдээгүй. Хэдийгээр өмнө нь Бурхан Содомыг устгасан ч өнөөдрийн Содомд өнгөрсөн үеийнхтэй адил хандахгүй—энэ нь шууд устгагдахгүй, харин эхлээд байлдан дагуулагдаж, дараа нь шүүгдэж, эцэстээ

мөнхийн шийтгэл хүртэнэ. Эдгээр нь ажлын алхмууд бөгөөд эцэстээ өнөөдрийн Содом дэлхийн урьдын сүйрэлтэй адилхан дарааллаар бүрмөсөн устгагдана—энэ нь Бурханы төлөвлөгөө юм. Бурханы харагдах өдөр нь өнөө үеийн Содомыг албан ёсоор яллах өдөр бөгөөд Тэрээр үүнийг аврахын төлөө Өөрийгөө илчлэхгүй. Тиймээс Бурхан: “Би ариун хаанчлалд харагдаж, бузар газар нутгаас Өөрийгөө нууна” гэж хэлсэн юм. Өнөөдрийн Содом ариун бус учраас Бурхан үүнд үнэхээр харагдахгүй, харин үүнийг гэсгээхийн тулд энэ аргыг ашигладаг—чи үүнийг тодорхой харсан бус уу? Газар дээрх хэн ч Бурханы жинхэнэ нүүр царайг харж чадахгүй гэж хэлж болно. Бурхан хүнд хэзээ ч харагдаагүй ба Бурхан тэнгэрийн аль түвшинд байдгийг хэн ч мэдэхгүй. Үүнээс болоод өнөөдрийн хүмүүс ийм нөхцөл байдалтай байгаа юм. Хэрвээ тэд Бурханы нүүр царайг харсан бол тэр нь тэдний төгсгөл илчлэгдэх үе, дор бүрнээ төрлийнхөө дагуу ангилагдах үе байх байсан нь лавтай. Өнөөдөр бурханлаг чанарын үг хүмүүст шууд харагдаж, хүн төрөлхтний эцсийн өдрүүд хүрэлцэн ирсэн ба төдийлөн удаан үргэлжлэхгүй гэдгийг зөгнөдөг. Бурхан бүх хүнд харагдах үед хүмүүс шалгалтад өртөхийн нэг тэмдэг энэ билээ. Тиймээс хэдийгээр хүмүүс Бурханы үгийг эдэлдэг ч өөрсдөд нь асар их гамшиг тохиох гэж буй мэт муу ёрын мэдрэмж үргэлж төрдөг. Өнөөдрийн хүмүүс хөлдүү цэвдэг газарт байгаа бор шувуу шиг, үхэл тэдэнд өр тулгаж, амьд үлдэх ямар ч аргагүй болгодог мэт байдаг. Хүний төлөх ёстой үхлийн өрнөөс үүдэн хүмүүс бүгд эцсийн өдрүүд нь ирснийг мэдэрдэг. Энэ нь орчлон ертөнц даяар хүмүүсийн зүрх сэтгэлд тохиолдож байгаа зүйл бөгөөд хэдийгээр тэдний нүүрэн дээр илчлэгдээгүй байдаг ч зүрх сэтгэлд нь байгаа зүйл Миний нүднээс нуугдах чадваргүй—хүний бодит байдал энэ юм. Магадгүй ихэнх үгийг бүрэн зохистой ашиглаагүй байх—гэхдээ яг эдгээр үг асуудлыг хангалттай харуулдаг. Бурханы амаар хэлэгдсэн үг өнгөрсөн үеийнх ч бай, эсвэл өнөө үеийнх ч бай хамаагүй, нэг бүрчлэн биелэх болно; тэдгээр нь хүмүүсийн өмнө баримтуудыг харуулж, нүдийг нь хужирлана—тэр үед хүмүүсийн нүд гялбаж, будилна. Өнөөдөр ямар эрин үе болохыг та нар тодорхой хараагүй л байна уу?

30-Р БҮЛЭГ

Зарим хүн Бурханы үгийг багахан ухаардаг байж болох ч нэг нь ч мэдрэмждээ итгэдэггүй; сөрөг байдалд орохоос ихэд айдаг. Тиймээс тэдний хувьд баяр хөөр, уйтгар гуниг үргэлж ээлжилж байдаг. Бүх хүний амьдрал гаслангаар дүүрэн байдаг гэж хэлэхэд буруудахгүй; цаашилбал, бүх хүний өдөр тутмын амьдралд цэвэршүүлэлт байдаг боловч хэн ч өдөр бүр сүнсээ чөлөөлдөггүй гэж би хэлж чадна, энэ нь яг л толгой дээрээс нь асар том гурван уул дарж буй мэт байдаг. Тэдний хэн нь ч өдөржин аз жаргал, баяр хөөртэй амьдардаггүй, багахан аз жаргалтай байхдаа ч гэсэн зүгээр л юу ч болоогүй мэт царайлах гэж оролдож

байдаг. Хүмүүсийн зүрх сэтгэлд үргэлж ямар нэгэн зүйлийг дуусгаагүй мэдрэмж байдаг. Тиймээс тэдний зүрх сэтгэл тогтвортой байдаггүй; ингэж амьдарснаар аливаа зүйл хий хоосон, шударга бус санагддагийн дээр Бурханд итгэх итгэлийн тухайд гэвэл завгүй агаад цаг заваар хомс, эс бөгөөс Бурханы үгийг идэж, уух цаг байдаггүй, эсвэл Бурханы үгийг хэрхэн зүй ёсоор идэж, уухаа мэддэггүй. Тэдний нэгнийх нь ч зүрх сэтгэл амар тайван, гэгээн тунгалаг, тууштай байдаггүй. Тэд үргэлж бүрхэг тэнгэрийн дор амьдарч байсан мэт, хүчилтөрөгчгүй орон зайд амьдардаг мэт байдаг болохоор амьдралдаа будилахад хүрсэн. Бурхан үргэлж хүмүүсийн сул тал руу шууд хандан ярьж, үргэлж эмзэг газар луу нь цохидог, та нар Түүний ярианы туршид өнгө аясыг нь тодорхой ажиглаагүй гэж үү? Бурхан хүмүүст хэзээ ч гэмших боломж өгөөгүй бөгөөд Тэр бүх хүнийг хүчилтөрөгчгүй “саран” дээр амьдруулдаг. Эхнээсээ өнөөдрийг хүртэл Бурханы үг өнгөн дээрээ хүний уг чанарыг ил болгосон боловч эдгээр үгийн мөн чанарыг хэн ч тодорхой ойлгож чаддаггүй. Хүний мөн чанарыг ил болгосноор хүмүүс өөрсдийгөө мэдэж авч, тэгснээр Бурханыг мэдэж авдаг юм шиг харагдаж байгаа ч мөн чанартаа энэ зам биш юм. Бурханы үгийн өнгө аяс, илүү гүн гүнзгий байдлаас Бурхан, хүн хоёрын хоорондох тодорхой ялгаа харагддаг. Энэ нь Бурхан бол хүршгүй агаад ойртошгүй гэсэн мэдрэмждээ хүмүүсийг өөрийн эрхгүй итгэхэд хүргэдэг; Бурхан бүх зүйлийг ил гаргадаг бөгөөд Бурхан, хүн хоёрын харилцааг хэн ч урьдын байсан руу нь буцааж чадахгүй юм шиг санагддаг. Бурханы бүх айлдварын зорилго нь үг ашиглан бүх хүнийг “унагааж”, ингэж ажлаа гүйцэлдүүлэх гэдгийг ойлгоход хэцүү биш. Эдгээр нь Бурханы ажлын алхмууд билээ. Гэсэн ч хүмүүсийн оюун санаандаа итгэдэг зүйл энэ биш юм. Бурханы ажил оргилдоо хүрэх дөхөж байгаа ба хамгийн их ялган танихуйц үр дүндээ хүрэх дөхөж байгаа нь агуу улаан лууг байлдан дагуулдаг, өөрөөр хэлбэл, чуулганууды хөгжүүлэн цэцэглүүлж, бие махбодтой болсон Бурханы талаарх үзэл хэнд ч байхгүй болж, эсвэл бүх хүн Бурханыг мэддэг гэж тэд үздэг. Гэсэн ч Бурхан юу гэж хэлснийг уншицгаая: “Хүмүүсийн оюун бодолд Бурхан бол Бурхан, Түүнтэй харьцахад амаргүй, харин хүн бол хүн, хүн амархан цадигаа алдаж болохгүй… Үүний үр дүнд тэд Миний өмнө үргэлж даруу агаад тэвчээртэй байдаг; тэд Надтай нийцтэй байх чадваргүй, учир нь тэдэнд хэтэрхий олон үзэл байдаг.” Бурхан юу хэлэх, хүн юу хийхээс үл хамааран хүмүүс үнэхээр Бурханыг мэдэх чадваргүй гэдгийг үүнээс харж болно; мөн чанарынхаа гүйцэтгэдэг үүргээс хамааран тэд эцсийн эцэст Бурханыг яагаад ч мэдэх чадваргүй юм. Тиймээс хүмүүс өөрсдийгөө тамын хөвгүүд гэж үзэх үед Бурханы ажил дуусах болно. Удирдлагаа бүхэлд нь дуусгахын тулд уур хилэнгээ хүмүүст гаргаж, тэднийг шууд яллаж, эцэст нь үхэх ял оноох хэрэг Бурханд байхгүй. Тэрээр ажлаа дуусгах нь явдлын далимд болдог мэт, өчүүхэн ч хүчин чармайлт гаргахгүйгээр цаг заваараа гүйцэтгэдэг зүйл нь мэт Өөрийн тааваар ердөө л ойр зуурын юм ярьдаг. Гаднаасаа бол Бурханы ажил тодорхой хэмжээгээр яаралтай юм шиг харагддаг хэр нь Бурхан юу ч хийсэнгүй, Тэр ярихаас өөр юм хийдэггүй. Чуулганууды дундах

ажил нь өнгөрсөн үеийнхтэй адил өргөн цар хүрээтэй биш: Бурхан хүмүүсийг элсүүлж, эсвэл хөдөөгүй, тэднийг ил болгодоггүй, тийм ажил хэтэрхий шалдар булдар юм. Бурхан тийм ажил хийхэд анхаардаггүй юм шиг санагддаг. Тэр хэлэх учиртай зүйлийнхээ багахан хэсгийг хэлснийхээ дараа эргэж хараад ул мөргүй алга болдог, энэ нь угаасаа Түүний айлдвар дуусаж буй дүр зураг юм. Энэ мөч ирэх үед бүх хүн нойрноосоо сэрнэ. Хүн төрөлхтөн мянга мянган жилийн туршид үхширтэл унтсан, энэ бүх хугацаанд тэд гүн нойрсож байсан. Тэгээд хүмүүс олон жилийн турш зүүдэндээ нааш цааш гүйж, сэтгэл дотроо байгаа шударга бус байдлын талаар ярьж чадахгүй, бүр зүүдэндээ хашхирч байсан. Тиймээс тэд “зүрх сэтгэлдээ бага зэргийн уйтгар мэдэрдэг”—гэвч сэрэх үедээ жинхэнэ баримтуудыг олж илрүүлэн “Аан, ийм зүйл болж байгаа байх нь!” хэмээн уулга алддаг. Тиймээс “Өнөөдөр ихэнх хүн бөх нойрссон хэвээр байна. Хаанчлалын сүлд дуу эгшиглэх үед л тэд нойрмог нүдээ нээж, зүрх сэтгэлдээ бага зэргийн уйтгар мэдэрдэг” гэж хэлдэг.

Хэзээ ч хэний ч сүнс чөлөөлөгдөж байгаагүй, хэзээ ч хэн нэгний сүнс эрх дураараа, аз жаргалтай байгаагүй. Бурханы ажил бүрмөсөн дуусах үед хүмүүсийн сүнс чөлөөлөгдөх болно, учир нь хүн бүрийг төрлийнх нь дагуу ангилах учраас бүгдийнх нь зүрх сэтгэл тайван байна. Яг л хүмүүс алс холын аянаас гэртээ ирээд зүрх сэтгэл нь тайвширч байгаа мэт байдаг. Гэртээ ирэнгүүт хүмүүст дэлхий ертөнц хоосон, шударга бус санагдахаа больж, харин гэртээ амар тайван амьдрах болно. Бүх хүн төрөлхтний дунд нөхцөл байдал ийм байх болно. Тиймээс “хүмүүс өөрсдийгөө Сатаны хүлээснээс чөлөөлж хэзээ ч чадаагүй” гэж Бурхан хэлдэг. Хэн ч махан биед байхдаа өөрсдийгөө энэ байдлаас чөлөөлж чаддаггүй. Хүний янз бүрийн бодит байдлын талаар Бурхан юу хэлдгийг түр зуур хойш тавиад хүнд хараахан илчлээгүй байгаа Бурханы нууцуудын талаар л ярьцгаая. “Миний бие битүү өргөстэй, тэдний хувьд жигшмээр зүйл аятай хүмүүс Над руу тоо томшгүй олон удаа доогтой харцаар харж байсан, тиймээс хүмүүс Надад зэвүүцэж, хэрэггүй амьтан гэж үздэг.” Эсрэгээрээ, хүний үнэн дүр төрх үнэн хэрэг дээрээ Бурханы үгэнд илчлэгддэг: Хүн зарааны өргөсөөр бүрхэгдсэн байдаг, түүнд аятайхан зүйл юу ч байхгүй учраас Бурхан хүнийг улам их үзэн яддаг, учир нь хүн бол ямар ч бахдам зүйл үгүй өргөст зараанаас өөр юу ч биш билээ. Өнгөн дээрээ эдгээр үг нь Бурханд хандах хүний үзлийг тодорхойлж байгаа мэт харагддаг боловч үнэн хэрэгтээ Бурхан хүний хөргийг дүр төрх дээр нь үндэслэн зурж байгаа юм. Эдгээр үг нь хүнийг дүрслэх Бурханы дүрслэл бөгөөд Бурхан хүний зурган дээр тогтоогч уусмал цацсан мэт байдаг; тиймээс орчлон ертөнцөд хүн нүүр бардам дүр төрхтэй агаад бүр хүмүүсийг гайхшируулдаг. Үг хэлж эхлэх үеэсээ л Бурхан хүнтэй хийх агуу тулааныхаа төлөө Өөрийн хүчийг тараан байрлуулсаар ирсэн. Тэр баримтуудыг хүнд зориулан дэлгэн тавьж байгаа их сургуулийн алгебрын профессор шиг нотолгоо, сөрөг нотолгоо гэх мэт баримтуудаар батлагдсан зүйлсийг жагсааж бүх хүнийг бүрэн үнэмшүүлдэг. Энэ бол Бурханы бүх үгийн зорилго бөгөөд үүний улмаас Бурхан хүн рүү дараах нууцлаг үгийг хайгадуухан чулууддаг: “Би бол товчхондоо хүний зүрх сэтгэлд огтхон ч үнэ

цэнгүй, онцын шаардлагагүй гэр ахуйн бараа юм.” Эдгээр үгийг уншаад хүмүүс зүрх сэтгэлдээ өөрийн эрхгүй залбирч, Бурханд өртэйгөө мэдэж авдаг учраас өөрсдийгөө яллахад хүрч, хүн үхэх учиртай агаад өчүүхэн төдий ч үнэ цэнгүй гэж үздэг. Бурхан “Үүний улмаас Би өнөөдрийн ийм нөхцөл байдалд орчхоод байна” гэж хэлсэн нь өнөөдрийн бодит нөхцөл байдалтай холбож үзэх үед хүмүүс өөрсдийгөө яллахад хүргэдэг. Энэ бодит үнэн биш гэж үү? Хэрвээ чамд өөрийг чинь мэдүүлбэл чиний амнаас “би үнэхээр үхэх ёстой!” гэх мэтийн үг гарах болов уу? Хүний жинхэнэ нөхцөл байдал ийм, үүнийг хэтэрхий их бодох хэрэггүй, энэ нь зүгээр л тохирсон жишээ юм.

Бурхан хүнээс уучлал болон хүлээцтэй байдлыг гуйх үед, нэг талаараа хүмүүс Бурхан тэднээр тохуурхаж байна гэж хардаг бөгөөд нөгөө талаар тэд мөн өөрсдийн тэрслүү байдлыг хардаг—тэд зүгээр л Бурхан хүний төлөө байдгаараа чармайн зүтгэхийг хүлээж байдаг. Хүмүүсийн үзлийн тухай ярихынхаа хажуугаар Бурхан Өөрийгөө хүний амьдралын гүн ухаанд ч, хүний хэлэнд ч чадамгай биш гэж хэлдэг. Тиймээс нэг талаараа энэ нь хүмүүсийг эдгээр үгийг бодитой Бурхантай харьцуулахад хүргэдэг, харин нөгөө талаар тэд Бурханы үгээс санаа зорилгыг нь хардаг. Бурхан тэднийг дооглож байгаа, учир нь Бурхан хүний үнэн нүүр царайг илчилж байгаа ба Тэр үнэндээ хүмүүст Бурханы жинхэнэ нөхцөл байдлын талаар хэлээгүй гэдгийг тэд ойлгодог. Бурханы үгийн гол утга учир нь хүнд хандах доог тохуу, наргиан, егөөдөл, үзэн ядалтаар дүүрсэн байдаг. Яг л хүн юу ч хийсэн хуулийг гуйвуулж, хээл хахууль авч байдаг мэт байдаг; хүмүүс завхай зайдан бөгөөд Бурханыг үг хэлэхээр амаа нээх үед тэд балмагдан чичирч, тэдний талаарх үнэн бүхэлдээ ил болж, хүний нүүр харахаас ичмээр байдалд хүрэх вий гэдгээс гүнээ айдаг. Гэхдээ баримт бол баримт. Хүнийг “гэмшсэний” төлөө Бурхан айлдваруудаа зогсоодоггүй; хүмүүс хэдий чинээ хэлэхийн аргагүй ичиж, үгээр илэрхийлэхийн аргагүйгээр сандарна, Бурхан Өөрийн дүрэлзсэн харцаар тэдний царайг төдий чинээ ихээр ширтдэг. Түүний амнаас гарсан үг хүний бүхий л муухай үйл хэргүүдийг ил болгодог—зөвхөн энэ нь л шударга агаад алагчлахгүй байгаа хэрэг, үүнийг л Чинтиан[a] гэж нэрлэдэг, энэ бол хамгийн дээд шатны ардын шүүлт юм. Тиймээс хүмүүс Бурханы үгийг унших үедээ гэнэт зүрхний шигдээс болж, цусны даралт нь ихэсдэг бөгөөд яг л зүрхний титэм судасны өвчнөөр шаналж байгаа мэт, тархины цус харвалтаар өвөг дээдэстэйгээ уулзахаар өрнийн диваажин руу буцах гэж байгаа мэт болдог, энэ нь Бурханы үгийг унших үед тэдэнд илэрдэг хариу үйлдэл юм. Хүн олон жилийн хүнд хүчир ажлынхаа улмаас сул дорой болсон, бүхэлдээ өвчилсөн байдаг ба зүрхнээсээ эхлээд судас, бүдүүн гэдэс, нарийн гэдэс, ходоод, уушги, бөөр гэх мэт түүний бүх юм нь өвчтэй байдаг. Түүний бүхий л биед эрүүл зүйл юу ч байдаггүй. Тиймээс Бурханы ажил хүний үл хүрэх түвшинд хүрдэггүй боловч хүмүүсийг өөрсдийгөө мэдэхэд хүргэдэг. Хүний бие вируст

[a] Чинтиан (Qingtian): Энэхүү нэр томьёог Хятадын хаант улсын үед шударга шүүгчид хамаатуулан ашигладаг байсан.

эзлэгдсэн байдаг учраас, бас хөгширчихсөн учраас түүний үхэх өдөр ойртсон ба буцах зам байдаггүй. Гэхдээ энэ бол асуудлын зөвхөн нэг хэсэг; дотоод утга учир нь хараахан илчлэгдээгүй байна, учир нь хүний өвчний эх сурвалжийг эрж хайж байгаа. Үнэн хэрэгтээ Бурханы ажил бүхэлдээ дуусах үе нь Түүний газар дээрх ажил дуусах үе биш юм, учир нь ажлын энэ алхам дуусангуут хожмын ажлыг бие махбодоор гүйцэтгэх ямар ч аргагүй байх бөгөөд үүнийг Бурханы Сүнс дуусгах шаардлагатай болно. Тиймээс Бурхан “Хуйлмал номыг албан ёсоор нээх үе нь мөн орчлон ертөнц даяарх хүмүүс гэсгээгдэх үе, Миний ажил оргилдоо хүрэх үе, дэлхий даяарх хүмүүс шалгалтад өртөх үе юм” гэж хэлсэн. Бие махбод дахь ажил дуусах үе нь Бурханы ажил оргилдоо хүрэх үе биш—энэ удаагийн оргил нь ердөө л энэ үе шатны ажилтай хамаатай ба энэ нь бүхий л удирдлагын төлөвлөгөөний оргил биш юм. Тиймээс хүнээс шаардах Бурханы шаардлага өндөр биш. Тэр хүмүүсээс ердөө өөрсдийгөө мэдэхийг, тэгснээрээ Бурханы хүсэл биелчихсэн байх ажлын дараагийн алхамд үйлчлэхийг л шаарддаг. Бурханы ажил өөрчлөгдөхийн сацуу хүмүүсийн “ажлын хэсэг” өөрчлөгддөг. Өнөөдөр бол Бурханы газар дээрх ажлын үе шат бөгөөд тиймээс тэд хамгийн анхан шатанд ажиллах ёстой. Ирээдүйд улс үндэстнийг удирдах хэрэгтэй болох бөгөөд тиймээс тэднийг “Төв Хороонд” дахин томилох болно. Хэрвээ тэд хилийн чанадад зочилбол, гадаад руу явах журамтай харьцах хэрэгтэй болно. Тийм цаг үеүдэд тэд төрөлх нутгаасаа алс хол гадаадад байх болно—гэхдээ энэ нь ч мөн Бурханы ажлын шаардлагуудаас шалтгаалах юм. Хүмүүсийн хэлснээр “Бид шаардлагатай үед Бурханы төлөө амиа өгөх болно”—ирээдүйд алхах ёстой зам энэ биш гэж үү? Хэн тийм амьдралыг эдэлсэн юм бэ? Хүн хаа сайгүй аялж, хилийн чанадад зочилж, хөдөө нутагт удирдамж өгч, жирийн иргэдийн дунд өөрсдийгөө уусгаж болно, тэд мөн өндөр түвшний байгууллагын гишүүдтэй улс орны чухал хэрэг явдлыг ярилцаж чадна; мөн шаардлагатай үед тамын амьдралыг биечлэн амсаж, үүнийхээ дараа буцан ирээд тэнгэрийн ерөөлийг мөн л эдэлж чадах болно. Эдгээр нь хүний ерөөл биш гэж үү? Бурхантай харьцуулагдах хэн байх юм бэ? Хэн бүх улс үндэстнүүдээр аялсан юм бэ? Ямар ч заагч, эсвэл тайлбаргүй бол хүмүүс Бурханы зарим үгийг үнэн хэрэгтээ бага зэрэг л ойлгож чадах болно—тэд зүгээр л өөрсдөдөө итгэлгүй байдаг ба Бурханы ажлыг өнөөдрийг хүртэл сунгасан зүйл нь энэ юм. Хүмүүст хэтэрхий их зүйл дутагддаг, Бурханы хэлснээр “тэдэнд юу ч байхгүй” учраас өнөөдрийн ажил нь тэдэнд асар их бэрхшээл учруулдаг; үүнээс гадна тэдний сул тал нь аяндаа Бурханы амыг хязгаарласан—яг эдгээр зүйл Бурханы ажилд саад болж байгаа биш гэж үү? Та нар үүнийг харахгүй л байна уу? Бурханы хэлдэг бүхэнд нууцлаг утга учир байдаг. Бурхан ярих үедээ ойрын асуудлыг барьж авдаг бөгөөд яг л ёгт үлгэр шиг Түүний хэлдэг бүх үг нь гүн гүнзгий сургаалыг агуулж байдаг. Эдгээр энгийн үгэнд гүн гүнзгий утга агуулагддаг, тийнхүү чухал асуудлуудыг тайлбарладаг—Бурханы үг энэ тал дээр шилдэг нь биш гэж үү? Чи үүнийг мэдэх үү?

31-Р БҮЛЭГ

Бурханы зан чанар Бурханы бүх айлдварт шингэсэн байдаг боловч Түүний үгийн гол учиг нь бүх хүн төрөлхтний тэрслүү байдлыг илчилж, тэдний дуулгаваргүй байдал, бусдад захирагддаггүй зан, шударга бус байдал, зөв шударга бус байдал, Бурханыг үнэхээр хайрлах чадваргүй байдал гэх мэт зүйлсийг ил болгосноор, хүмүүсийн биеийн нүх сүв бүхэн нь Бурханыг эсэргүүцдэг, хялгасан судас нь хүртэл Бурханыг үл тоомсорлодог гэж Бурхан хэлэх хэмжээнд Түүний үг очсон. Хэрвээ хүмүүс эдгээр зүйлийг судалж шинжлэхээр хичээхгүй бол тэдгээрийг үргэлж мэдэж чадахгүй, хэзээ ч таягдан хаяж чадахгүй. Өөрөөр хэлбэл, Бурханыг эсэргүүцдэг вирус тэдэнд тархаж, эцэст нь цусны цагаан эс нь улаан эсийг нь залгиж, бүхий л биеийг нь улаан эсгүй болгож орхисон мэт байх болно; эцэстээ тэд цусны өвчнөөр нас барна. Энэ бол хүний бодит байдал, хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй. Агуу улаан луу цагариглан хэвтдэг газар нутагт төрсөн хүн болгонд, агуу улаан лууны хорыг илтгэсэн, жишээ болсон ядаж нэг зүйл байдаг. Тиймээс, ажлын энэ үе шатанд Бурханы үг даяарх гол учиг нь өөрийгөө мэдэж, өөрийгөө үгүйсгэж, өөрийгөө хаяж, өөрийгөө хөнөөх явдал байж ирсэн. Энэ бол эцсийн өдрүүдийн үеэрх Бурханы үндсэн ажил, ажлын энэ мөчлөг нь хамгийн дэлгэрэнгүй, бүрэн гүйцэт гэж хэлж болох юм—энэ нь, Бурхан эрин үеийг төгсгөхөөр төлөвлөж байгааг харуулдаг. Хэн ч үүнийг тааварлаагүй ч гэсэн бас урьдаас мэдэрч байсан зүйл юм. Хэдийгээр Бурхан ил тодоор хэлээгүй боловч хүмүүсийн мэдрэхүй маш хурц—цаг хугацаа богино гэдгийг тэд үргэлж мэдэрдэг. Хүн үүнийг хэдий чинээ их мэдэрнэ, эрин үеийн талаар төдий чинээ тодорхой мэдлэгтэй байдаг гэдгийг Би хэлж чадна. Энэ нь, дэлхийг хэвийн гэж харж байгаа учраас Бурханы үгийг үгүйсгэж байгаа биш юм; харин ч, Бурханы ажилладаг арга барилаар дамжуулан Бурханы ажлын агуулгыг мэдэх юм. Энэ нь Бурханы үгийн өнгө аясаар тодорхойлогддог. Бурханы айлдваруудын өнгө аяст хэний ч нээн илрүүлээгүй нууц байдаг бөгөөд мөн хүмүүс яг үүнд л орох хамгийн хэцүү байдаг. Хүмүүс Бурханы үгийг яагаад ойлгож чаддаггүйн гол шалтгаан нь тэд Бурханы ярьдаг өнгө аясыг хайхрахгүй байсаар байдаг—хэрвээ тэд энэ нууцыг сайтар эзэмшиж чадвал Бурханы үгийн талаар зарим нэг мэдлэгтэй болж чадна. Бурханы үг үргэлж нэг зарчмыг дагаж ирсэн нь: Бурханы үг бол бүх зүйл гэдгийг хүмүүст мэдүүлж, хүний бүх хүндрэл бэрхшээлийг Бурханы үгээр дамжуулан шийдвэрлэх юм. Сүнсний өнцгөөс харахад, Бурхан Өөрийн үйлсийг ил тод болгодог, хүний өнцгөөс харахад, Тэр хүмүүсийн үзлийг илчилдэг; Сүнсний өнцгөөс харахад, хүн Өөрийнх нь хүсэлд санаа тавьдаггүй гэж Тэр хэлдэг; хүний өнцгөөс харахад, Тэр хүмүүний туршлагын чихэрлэг, исгэлэн, гашуун, аагтай амтыг амсаж, салхиар ирж, борооноор буцаж, бас гэр бүлийн хавчлагыг туулж, амьдралын эрээн барааныг туулсан гэж хэлдэг. Эдгээр нь өөр өөр өнцгөөс хэлсэн үг юм. Түүнийг Бурханы ардуудтай ярих үед, энэ нь гэрийн эзэгтэй боолуудаа загнаж байгаа юм шиг, эсвэл хошин шогийн үзүүлбэр шиг

байдаг; Түүний үг хүмүүсийн нүүрийг улайлгаж, ичсэндээ нүүрээ хийх газаргүй болгож орхидог бөгөөд тэд өнгөрсөн дэглэмийн феодал ноёдод баригдаж хэрцгий эрүү шүүлт дор хэргээ улайж буй мэт байдаг. Бурханы ардуудтай ярих үедээ Бурхан, төв засгийн газар доторх шившигт явдлыг ил болгодог эсэргүүцэл хийж буй их сургуулийн оюутнууд шиг жолоогүй байдаг. Хэрвээ Бурханы бүх үг тохуурхангуй байсан бол хүмүүсийн хувьд тэдгээрийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байх байсан; тиймээс Бурханы хэлсэн үг шулуухан байдаг; тэдгээр нь хүнд зориулсан нууц түлхүүр агуулаагүй, харин хүний бодит байдлыг шууд хэлж өгдөг—энэ нь, хүнийг хайрлах Бурханы хайр нь зүгээр нэг үг төдий биш, харин бодитой гэдгийг харуулдаг. Хэдийгээр хүмүүс бодитой байдлыг үнэлдэг боловч Бурханыг гэсэн тэдний хайранд бодитой зүйл юу ч байдаггүй. Хүнд дутагдаж байгаа зүйл бол энэ юм. Хэрвээ Бурханыг гэсэн хүмүүсийн хайр бодитой биш бол, үүнээс болж бүх зүйл алга болох юм шиг, бүх зүйл бүхэлдээ хий хоосон, хийсвэр байх болно. Хэрвээ Бурханы гэх тэдний хайр орчлон ертөнцөөс даван гарвал тэдний байр суурь, ялгамж чанар, тэр ч бүү хэл эдгээр үг хоосон биш жинхэнэ байх болно—чи үүнийг харж байна уу? Хүнд тавих Бурханы шаардлагыг чи харсан уу? Хүн байр суурийн ашиг тусыг зүгээр нэг эдлэх биш, харин байр суурийн бодит байдлыг амьдран харуулах ёстой. Бурханы ардуудаас болон бүх хүнээс Бурханы гуйдаг зүйл нь энэ бөгөөд энэ нь ямар нэгэн агуу хоосон онол биш юм.

Яагаад Бурхан: “миний хийдэг бүхэн тэдний таалалд нийцүүлэх гэсэн оролдлого мэт байдаг, үүний улмаас тэд үргэлж Миний ажил хэрэгт зэвүүцдэг” гэх мэтийн үг хэлдэг вэ? Хүн Бурханыг жигшиж буйн бодит илрэлийн талаар чи ярьж чадах уу? Хүмүүсийн үзлээр бол, хүн Бурхан хоёр “хайранд умбаж” байдаг бөгөөд өнөөдөр, хүмүүс Бурханыг ганцхан үмхээд залгихыг дуртайяа хүсэх хэмжээнд хүртлээ Бурханы үгийг хүсэн эрмэлзэх болсон—гэсэн ч Бурхан дараах үгсийг хэлдэг: “Хүн Намайг үзэн яддаг. Миний хайрыг яагаад хүн үзэн ядалтаар хариулдаг юм бэ?” Энэ нь хүмүүсийн доторх эрдсийн орд бус уу? Үүнийг ухаж гаргах ёстой бус уу? Энэ бол хүмүүсийн эрэл хайгуул дахь дутагдал; шийдвэрлэх учиртай томоохон асуудал, Бурханыг мэдэх хүний мэдлэгийн зам дээр зогсож байгаа, хүний төлөө арилгах ёстой арслан—үүнийг л хийх ёстой бус уу? Хүн гахай шиг ямар ч ой санамжгүй, үргэлж зугаа цэнгэлд шунадаг учраас Бурхан хүнд ой санамж муудах өвчинд зориулсан эм өгдөг—Тэр илүү их ярьж, улам ихийг хэлж, хүмүүсийг чихнээс нь чангааж байгаад, анхааралтай сонсгуулж, сонсголын аппарат тааруулж өгдөг. Түүний зарим үгийн тухайд гэвэл, ганцхан удаа хэлээд асуудлыг шийдвэрлэж чадахгүй; ахин дахин хэлэх ёстой, учир нь “хүмүүс амьдралдаа үргэлж мартамхай, бүх хүн төрөлхтний амьдралын өдрүүд нь эмх замбараагүй байдаг.” Ийм байдлаар хүмүүс, “цаг гарахаараа уншдаг, завтай үедээ сонсдог, завгүй бол орхидог; хэрвээ өнөөдөр үг хэлбэл анхаарлаа хандуулдаг, харин маргааш нь хэлэхгүй бол сэтгэлийнхээ мухарт хийж орхих” байдлаасаа аврагдаж чадна. Хүмүүсийн уг чанарын тухайд гэвэл, хэрвээ өнөөдөр Бурхан тэдний бодит байдлын талаар ярьж,

тэд энэ талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй болж авсан бол, тэд харамслаар дүүрэх боловч, дараа нь тэд өөрсдийн хуучин байдалдаа эргэн орж, Бурханы үгийг салхинд хийсгэж, тэдэнд сануулах үед л дээр дүрсэлсэн үйл явдлыг давтах болно. Тиймээс чи ажиллаж, эсвэл ярьж байхдаа хүний энэ гол чанарыг бүү март; ажиллаж байхдаа энэ голчанарыг хаявал алдаа болно. Бүх ажлыг хийхдээ хүмүүсийн үзлийг авч үзэж ярих нь онцгой чухал юм. Ялангуяа, чи Бурханы үгэн дээр өөрийн мэдлэг ухааныг нэмэрлэж, тэдэнтэй ярилцах ёстой. Энэ бол хүмүүсийг хангаж, тэдэнд өөрсдийгөө мэдэх боломжийг олгох зам юм. Бурханы үгийн агуулган дээр үндэслэн хүмүүсийг хангаснаар тэдний бодит байдлыг ухаарах боломжтой болох нь гарцаагүй. Бурханы үгээс хүний бодит байдлыг хангалттай ухаарч, тэгснээрээ тэднийг хангадаг—иймээс Би “Бурхан газар дээр найрын ширээнд суух урилгыг хүлээн авсан” гэдгийг цохон тэмдэглэсэн Бурханы үгийн талаар цаашид ярихгүй.

32-Р БҮЛЭГ

Бурханы үг хүмүүсийг хуйхаа маажихад хүргэдэг; ярих үедээ Бурхан хүнээс зайлсхийж агаарт үгээ хэлж байгаа мэт, хүний үйл хэрэгт дахин анхаарал хандуулах бодол Түүнд огт байхгүй, хүний биеийн хэмжээг огт тоохгүй байгаа мэт, Түүний хэлж буй үг хүмүүсийн үзэлд биш харин Бурханы анхны санааны дагуу хүнээс зайлсхийхэд чиглэж байгаа мэт байдаг. Тоо томшгүй олон шалтгааны улмаас хүний хувьд Бурханы үг ухаж ойлгохын аргагүй байдаг. Үүнд гайхах зүйлгүй. Бурханы бүх үг нь анхнаасаа хүмүүст ноу-хау өгөх буюу арга мэх сургах зорилготой байгаагүй; харин тэдгээр нь эхнээсээ өнөөдрийг хүртэл Бурханы ажиллаж ирсэн арга барилуудын нэг юм. Мэдээж Бурханы үгээс хүмүүс нууцуудтай холбоотой зүйлсийг, Петр, Паул, Иовтой хамаатай зүйлсийг олж авдаг—гэхдээ энэ нь тэдний хүрэх учиртай, тэдний хүрч чадах зүйл бөгөөд биеийн хэмжээндээ тааруулан эдгээр зүйлд хүрэхийн тулд хүрч чадах газраа хүртэл явсан. Бурханы хүрэхийг шаарддаг үр дүн тийм өндөр биш ч яагаад Тэр маш олон үгийг хэлсэн юм бэ? Энэ нь Түүний ярьдаг гэсгээлттэй холбоотой агаад энэ бүгд нь хүмүүсийг анзаараагүй байхад аяндаа биелэгддэг. Өнөөдөр хүмүүс Бурханы үгийн дайралтын дор асар их зовлонг туулдаг. Өнгөцхөн харахад тэдний хэн ч харьцалт амсаагүй мэт харагддаг боловч хүмүүс ажлаа хийхдээ чөлөөтэй болж эхэлсний дээр үйлчлэл үзүүлэгчид Бурханы ардууд болж өргөгдсөн—үүнээс тэд бүгд баяр цэнгэлд орсон гэж хүмүүст харагддаг. Үнэндээ бодит байдал дээр тэд бүгд цэвэршүүлэлтээс илүү хатуу ширүүн гэсгээлт рүү орсон. Бурханы хэлдгээр “Миний ажлын үе шатууд нэг нь нөгөөтэйгөө нягт холбоотой, нэг бүр нь бүр илүү өндөр байдаг.” Бурхан ёроолгүй нүхнээс үйлчлэл үзүүлэгчдийг өргөж, гэсгээлт нь улам илүү аймшигтай байдаг гал болон хүхэрт нуур руу тэднийг хаясан. Тиймээс тэд бүр ч илүү их зовлон бэрхшээлийг туулж, үүнээс зугтаж бараг чаддаггүй. Ийм гэсгээлт бүр ч илүү

аймшигтай бус уу? Илүү өндөр ертөнцөд орчхоод яагаад хүмүүст аз жаргалаас илүү их уй гашуу төрдөг юм бэ? Тэднийг Сатаны гараас аваад агуу улаан луунд өгсөн гэж яагаад хэлдэг юм бэ? “Ажлын сүүлчийн хэсгийг агуу улаан лууны гэрт хийж дуусгана” гэж Бурхан хэзээ хэлснийг чи санаж байна уу? Бурхан “Эцсийн зовлон бэрхшээл бол агуу улаан лууны өмнө Бурханы төлөө хүчтэй, цангинасан гэрчлэл хийх явдал юм” гэж хэзээ хэлснийг чи санаж байна уу? Хэрвээ хүмүүсийг агуу улаан луунд өгөөгүй бол тэд түүний өмнө гэрчлэл хийж яаж чадах юм бэ? Өөрийгөө хөнөөчхөөд “Би диаволыг ялчихлаа” гэх үгийг хэн хэлж байсан юм бэ? Махан биеэ дайсан хэмээн үзээд, амиа хорлосны бодит ач холбогдол нь хаана байна вэ? Бурхан яагаад ингэж хэлсэн бэ? “Би хүмүүсийн шархыг биш, харин шархлаагүй хэсгийг нь харж, үүнээс Би баяр хөөрийг олж авдаг.” Хэрвээ Бурхан шархлаагүй хүмүүсийг Өөрийн илэрхийлэл болгохыг хүсдэг нь үнэн байсан бол яагаад Тэр хүний үзэл рүү дайрах гэж хүний өнцгөөс тэвчээртэйгээр, чин сэтгэлээсээ маш олон үгийг хэлсэн юм бэ? Яах гэж Тэр ийм зүйлд санаа тавина гэж? Яагаад Тэр тийм зүйл хийх гэж шал дэмий Өөртөө яршиг төвөг удна гэж? Тэгэхээр Бурхан бие махбодтой болоход бодит ач холбогдол бий, Тэр махбод болж, ажлаа дуусгасныхаа дараа бие махбодыг “устгадаг юм биш” гэдгийг энэ харуулдаг. “Шижир алт гэж байх боломжгүй, төгс хүн гэж байх боломжгүй” гэж яагаад хэлсэн вэ? Эдгээр үгийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Бурхан хүний гол чанарын талаар ярих үед Түүний үг ямар утга илэрхийлдэг вэ? Хүмүүсийн энгийн нүдээр бие махбод юу ч хийх чадваргүй, хэтэрхий мөхөс харагддаг. Бурханы нүдэнд энэ нь огтхон ч чухал биш боловч хүмүүсийн хувьд энэ нь туйлын чухал асуудал юм. Тэд үүнийг үнэхээр шийдвэрлэх чадваргүй мэт, үүнийг тэнгэрлэг бүлэг биечлэн зохицуулах ёстой мэт байдаг боловч энэ бол хүмүүсийн үзэл бус уу? “Хүмүүсийн нүдэнд Би ердөө л тэнгэрээс бууж ирсэн ‘бяцхан од’, тэнгэр дэх бяцхан од бөгөөд Намайг өнөөдөр газар дээр ирэхийг Бурхан даалгасан. Ийм учраас хүмүүс ‘Би’ болон ‘Бурхан’ хэмээх үгсийн талаар илүү олон тайлбарыг бодож олсон.” Хүмүүс юу ч биш байтал Бурхан яагаад тэдний үзлийг өөр өөр өнцгөөс илчилдэг юм бэ? Энэ нь мөн л Бурханы мэргэн ухаан байж болох уу? Тийм үг инээдтэй биш гэж үү? Бурханы хэлдгээр “Хэдийгээр хүмүүсийн зүрх сэтгэлд Миний бий болгосон орон зай байдаг ч тэндээ амьдрахыг тэд Надаас шаарддаггүй. Харин ч тэд өөрсдийн зүрх сэтгэл дэх ‘Ариун Нэгнийг’ гэнэт хүрэлцэн ирэхийг хүлээдэг. Миний ялгамж чанар хэтэрхий ‘дорд’ учраас хүмүүсийн шаардлагад Би нийцдэггүй, тиймээс тэд Намайг ‘таягдан хаясан’.” Бурханы талаарх хүмүүсийн үнэлгээ “хэтэрхий өндөр” учраас Бурханы хувьд олон зүйл “хүршгүй” байдаг нь Түүнийг “хэцүү байдалд” оруулдаг. Хийж чаддаг байхыг Бурханаас шаарддаг зүйл нь тэдний үзэл гэдгийг хүмүүс огт мэддэггүй. “Ухаалаг хүн өөрийн цэцэн ухааны хохирогч болж магадгүй” гэдгийн бодит утга нь энэ бус уу? “Уул нь ухаантай боловч энэ удаа тэнэгтлээ” гэдэг хэрэг энэ үнэхээр мөн! Номлохдоо та нар хүмүүсийг өөрсдийнх нь үзлийн Бурханаас ангижруулдаг ч та нарын үзэл дэх Бурхан үгүй

болсон уу? “Би хүнээс тийм ихийг шаарддаггүй” хэмээх Бурханы үгийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Эдгээр үг нь хүмүүсийг сөрөг, замаа алдсан болгох бус, харин тэдэнд Бурханы үгийн талаар цэвэр ойлголт өгөхийн тулд байдгийг та нар ойлгов уу? Бие махбодтой болсон Бурхан үнэхээр хүмүүсийн төсөөлдөг шиг “өндөр дээд, төгс хүчит ‘Би’” мөн үү?

Хэдийгээр Бурханы хэлсэн бүх үгийг уншсан, тэдгээрийн талаар ерөнхий тоймыг өгч чадах хүмүүс байдаг боловч Бурханы эцсийн зорилго юу болохыг хэн хэлж чадах вэ? Хүн төрөлхтөнд энэ л дутагддаг. Бурхан ямар өнцгөөс ярихаас үл хамааран Түүний ерөнхий зорилго нь бие махбодтой Бурханыг хүмүүст мэдүүлэх явдал билээ. Хэрвээ Түүнд ямар ч хүн чанар байгаагүй бол—хэрвээ Түүнд тэнгэр дэх Бурханы шинж чанараас өөр юм байхгүй байсан бол—Бурхан тийм их юм хэлэх хэрэггүй байх байсан. Хүмүүст дутагддаг зүйл нь Бурханы үгтэй харилцан хамааралтай эх материал болдог гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, хүнд илэрдэг зүйл бол хүмүүсийн үзлийн талаар Бурханы хэлдэг зүйлийн цаад шалтгаан учраас хүмүүс Бурханы айлдваруудад үйлчилдэг. Угтаа энэ нь хүмүүсийн үзлийн талаар Бурханы хэлдэг зүйл дээр үндэслэдэг—зөвхөн ийм байдлаар л онол, бодит байдлын хослол гэж үүнийг хэлж болно, зөвхөн ингэж л хүмүүст өөрсдийгөө мэдэх нь чухал гэдгийг илүү үр дүнтэйгээр ойлгуулж болно. Хэрвээ бие махбодтой Бурхан хүмүүсийн үзэлтэй нийцдэг, Бурхан бас Өөрийнхөө талаар гэрчилдэг байсан бол ямар хэрэг байна? Яг энэ шалтгааны улмаас л Бурхан Өөрийн агуу хүч чадлыг тодотгохын тулд хүмүүсийн үзлийг ашиглан сөрөг талаас нь ажилладаг. Бурханы мэргэн ухаан энэ бус уу? Хүн болгоны төлөө Бурханы хийдэг бүхэн сайн юм чинь яагаад энэ удаад магтаж болохгүй гэж? Хэрвээ юмс тодорхой хэмжээнд хүрэх буюу цаг нь ирсэн бол чи шалгалтын дунд Петр шиг зүрх сэтгэлийнхээ гүнээс залбирал хэлж чадах байсан уу? Сатаны гарт байхдаа Петр шиг Бурханыг магтсан хэвээр байж чадсан цагт л чи “Сатаны хүлээснээс чөлөөлөгдөж, махан биеийг ялан дийлж, Сатаныг ялах” гэдгийн жинхэнэ утга учир гарах болно. Бурханы төлөөх илүү бодитой гэрчлэл энэ бус уу? Зөвхөн энэ нь л “бурханлаг чанар үйлчлэхээр гарч ирж, долоо дахин эрчимжсэн Сүнс хүн дээр ажилласнаар” хүрэх үр нөлөө бөгөөд энэ нь бас “Сүнс бие махбодоос гарч ирснээр” хүрэх үр нөлөө юм. Тийм үйлдлүүд нь бодитой бус уу? Чи бодит байдалд анхаарал хандуулдаг байсан атал өнөөдрийн бодит байдлын талаарх жинхэнэ мэдлэг чамд бий юу? “Би хүнээс тийм ихийг шаарддаггүй ч хүмүүс ингэж боддоггүй. Тиймээс хөдөлгөөн болгонд нь ‘даруу төлөв зан’ нь илэрдэг. Тэд үргэлж Миний урд Намайг хөтлөн явах үүрэгтэй, Намайг төөрөхөөс ихэд эмээж, Намайг уулын гүн дэх аглаг ой руу тэнүүчлэн явахаас ухаангүй айдаг. Ийм учраас хүмүүс Намайг үргэлж урагш хөтөлж, Намайг гяндан руу орох вий гэхээс ихэд айдаг.” Эдгээр энгийн үгийн талаар та нар ямар мэдлэгтэй вэ—та нар тэдгээрээс Бурханы үгийн үндсийг үнэхээр ухаарч чаддаг уу? Аль үзлийн чинь талаар Бурхан тийм үг хэлсэн бэ гэдэгт та нар анхаарал хандуулсан уу? Өдөр бүр та нар энэ гол зүйл дээр анхаарлаа хандуулдаг уу? Удахгүй гарах

дараагийн хэсгийн нэг өгүүлбэрт Бурхан “Гэсэн ч хүмүүс Миний хүслийг мэддэггүй, Миний тэдэнд хайрласан зүйл шаардлагад нь нийцэж чадахгүй байгаа мэт, эрэлт нь нийлүүлэлтээсээ давсан мэт Надаас юм гуйн залбирсаар байдаг” гэсэн. Энэ өгүүлбэрээс та нарт байдаг үзэл юу болохыг харж болно. Бурхан та нарын өнгөрсөн цаг хугацаанд юу хийснийг санадаггүй, мөрдөж мөшгөдөггүй, иймээс өнгөрсөн үеийн хэрэг явдлуудын талаар дахин бүү бод. Та нар ирээдүйн замд “сүүлчийн эрин үеийн Петрийн цог жавхааг” гаргаж чадах эсэх нь илүү чухал зүйл—үүнд хүрэх итгэл та нарт байна уу? Бурхан хүнээс Петрийг дуурайхаас өөр юуг ч хүсдэггүй, эцэстээ хүмүүс агуу улаан лууг шившиг болгох замыг тавиасай гэж хүсдэг юм. Үүний улмаас Бурхан “Хүмүүс Надтай хамтран ажиллахаар шийдсэн байгаасай л гэж Би найддаг. Надад сайхан хоол хийж өгч, Надад толгой хоргодоход тохирох газрыг зохицуулж өгөхийг… Би тэднээс гуйхгүй” гэж хэлсэн. Дэлхий дээр “Лэй Фэнгийн цог жавхааг” 1990-ээд онд авчрахыг хүмүүсээс хүсдэг боловч Бурханы гэрт “Петрийн өвөрмөц хэв маягийг” бий болгохыг Бурхан та нараас шаарддаг. Та нар Бурханы хүслийг ойлгов уу? Та нар үүний төлөө үнэхээр мэрийж чадах уу?

“Би орчлон ертөнц дээгүүр алхаж явахдаа бүхий л орчлон ертөнцийн хүмүүсийг ажигладаг. Газар дээрх бөөн хүн дундаас Миний ажилд тохиромжтой, Намайг үнэхээр хайрладаг хүн хэзээ ч байгаагүй. Тиймээс энэ мөчид Намайг сэтгэл хямран санаа алдахад хүмүүс нэн даруй дахин цугларахгүйгээр таран одож, тэднийг ‘бүгдийг нь нэг тороор барих’ вий гэхээс ихэд эмээдэг.” Магадгүй ихэнх хүмүүсийн хувьд эдгээр үгийг ойлгоход маш хэцүү байдаг ба тэд ингэж асуудаг: Яагаад Бурхан хүнээс ихийг шаарддаггүй мөртөө Түүний ажилд үнэхээр тохирох хэн ч байхгүйгээс болоод сэтгэл хямран санаа алддаг юм бэ? Энд зөрчилдөөн байна уу? Шууд утгаараа бол байгаа боловч бодит байдал дээр зөрчилдөж буй зүйл байхгүй. “Миний бүх үг Миний хүсдэг үр дүнг үзүүлэх болно” гэж Бурхан хэлж байсныг магадгүй чи санаж л байгаа. Бурхан бие махбодод ажиллах үед Түүнийг яг юу хийх гэж байгааг харах гэж үйлдэл бүрийг нь хүмүүс сайтар ажигладаг. Бурхан сүнсний ертөнц дэх Сатаныг онилсон шинэ ажлаа хэрэгжүүлэх үед, өөрөөр хэлбэл, бие махбодтой Бурханаас болоод газар дээрх хүмүүсийн дунд бүх төрлийн үзэл бий болдог. Бурхан сэтгэл хямран санаа алдах үед буюу хүний бүх үзлийн тухай Түүнийг ярих үед хүмүүс тэдгээртэй харьцахын тулд чадлаараа хичээдэг бөгөөд өөрсдийгөө ямар ч найдваргүй гэж итгэдэг хүмүүс хүртэл байдаг, учир нь Өөрийнх нь талаар үзэлтэй бүхэн Түүний дайсан мөн гэж Бурхан хэлсэн—иймийн учир хүмүүс хэрхэн “таран одохгүй” байж чадах билээ? Ялангуяа өнөөдөр гэсгээлт ирсэн үед Бурхан тэднийг арчиж хаяна гэдгээс хүмүүс бүр ч илүү их айдаг. Гэсгээгдсэнийх нь дараа Бурхан тэднийг “бүгдийг нь нэг тороор барина” гэж тэд боддог. Гэвч бодит байдал тийм биш: Бурханы хэлснээр “Би хүмүүсийг Өөрийн гэсгээлт дунд хэзээ ч зугтаалгахгүйгээр ‘хорихыг’ хүсдэггүй. Миний удирдлагад хүний үйл хэрэг дутагддаг учраас Өөрийн ажлыг амжилттай дуусгах боломжгүй байна, Миний ажил үр ашигтайгаар урагшлахад энэ нь саад болдог.” Бурхан бүх хүнийг үхүүлмэгцээ

Өөрийн ажлыг нэгмөсөн дуусгахыг хүсдэггүй—тэгэх ямар хэрэгтэй байна? Хүмүүс дээр ажиллаж, тэднийг гэсгээснээр Бурхан тэднээр дамжуулан Өөрийн үйл хэргийг ил болгодог. Бурханы үгийн өнгөнд аль хэдийн гэсгээлт байгааг хүмүүс хэзээ ч ухаараагүй учраас тэд ухамсартаа хэзээ ч ороогүй юм. Хүмүүс өөрсдийн шийдвэрийг илэрхийлэх чадваргүй учраас Бурхан Сатаны өмнө юу ч хэлж чаддаггүй нь Бурханы ажил урагшлахад садаа болдог. Тиймээс Бурхан ийнхүү хэлдэг: “Би нэгэнтээ хүнийг Өөрийнхөө гэрт зочноор урьсан боловч түүнийг зочин мэт урихын оронд Би түүнийг цаазын тавцанд аваачсан мэт Миний дуудлагын улмаас тэр нааш цааш гүйсэн. Тиймээс Миний гэр хоосон үлдсэн, учир нь хүн үргэлж Надаас зайлсхийж, үргэлж Надаас сэрэмжилж байсан. Энэ нь Намайг Өөрийн ажлын нэг хэсгийг хэрэгжүүлэх аргагүй болгосон юм.” Хүний ажилдаа гаргасан алдааны улмаас Бурхан Өөрийн шаардлагыг хүнд тодорхой тавьсан. Хүмүүс ажлын энэ алхмыг гүйцэлдүүлээгүй учраас Бурхан илүү их айлдваруудыг нэмсэн—Бурханы ярьдаг яг тэр “хүн дээрх ажлын өөр нэг хэсэг” нь энэ юм. Гэхдээ энэ нь өнөөдрийн ажилд тийм ч их нөлөөлөхгүй учраас Бурханы хэлсэн “бүгдийг нь нэг тороор барих болно” гэсний талаар Би нуршихгүй. Мэдээж, “Бүхий л орчлон ертөнцөд хандсан Бурханы үг”-энд Түүний олон үг хүнтэй харьцдаг боловч хүмүүс Бурханы хүслийг ойлгох ёстой; Түүний юу хэлэхээс үл хамааран санаа нь үргэлж сайн байдаг. Бурханы үгээ хэлэх арга барил маш олон учраас хүмүүс Бурханы үгийн тухайд зуун хувь итгэлтэй байж чаддаггүй агаад Бурхан дийлэнх үгээ ажлын шаардлагын улмаас хэлдгийн дээр бодит зүйл маш бага агуулдаг гэж үздэг. Энэ нь тэднийг өөрсдийн бодолдоо дарагдаж, будилахад хүргэдэг гэж хэлж болно—учир нь тэдний үзлээр бол Бурхан маш ухаалаг учраас тэдний хувьд огт хүрэхийн аргагүй агаад тэд юу ч мэдэхгүй, Бурханы үгийг хэрхэн идэхээ мэддэггүй мэт байдаг. Хүмүүс Бурханы үгийг хийсвэр агаад ээдрээтэй болгодог—Бурханы хэлдгээр “хүмүүс үргэлж Миний айлдварт амт нэмэхийг хүсдэг.” Тэдний санаа хэтэрхий төвөгтэй, Бурхан “хүрч чадахгүй” учраас Бурханы үгийн нэг хэсэг нь хүмүүсээс болж хязгаарлагдаж, Түүнийг шулуухан ярихаас өөр аргагүй болгодог. Хүмүүсийн шаардлага “хэтэрхий өндөр”, мөн тэдний төсөөлөл хэтэрхий баялаг учраас—тэд Сатаны үйл хэргийг харахын тулд сүнсний ертөнцийн хилийг давж чаддаг мэт байдаг—Бурхан үгээ багасгасан, учир нь Бурхан хэдий чинээ их ярина, хүмүүсийн царай төдий чинээ дүйнгэ болдог. Өөрсдийнхөө төгсгөлийг таамаглахын оронд яагаад тэд зүгээр л дуулгавартай байж болдоггүй юм бэ? Үүний ашиг тус хаана байна вэ?

33-Р БҮЛЭГ

Үнэндээ Бурханы хүмүүст хийсэн, тэдэнд өгсөн зүйлс дээр, түүнчлэн хүмүүсийн эзэмшдэг зүйл дээр үндэслээд үзэхэд хүмүүст тавьдаг Түүний шаардлага хэтэрсэн биш, Тэр тэднээс тийм ч ихийг шаарддаггүй гэж хэлж болно. Тэгвэл тэд Бурханыг

хангалуун байлгах гэж хичээхгүй байж яаж чадна вэ? Бурхан хүнд нэг зуун хувийг өгдөг, гэсэн ч Тэр хүмүүсээс ганц хувийн хэлтэрхийг л шаарддаг—энэ нь хэтэрхий их гэж үү? Бурхан дэмий төвөг удаж байна уу? Хүмүүс өөрсдийгөө мэддэггүй нь олон; тэд Бурханы өмнө өөрсдийгөө шалгадаггүй бөгөөд иймээс байнга урхинд ордог—үүнийг яаж Бурхантай хамтран ажиллаж байна гэж үзэж болох юм бэ? Хэрвээ Бурхан хүмүүст хүнд ачаа үүрүүлээгүй цаг байсан бол тэд шавар шиг үйрэх байсан ба өөрсдөдөө хийх зүйл олж чадахгүй байсан юм. Хүмүүс тийм л идэвхгүй юм уу сөрөг байдаг, Бурхантай идэвхтэйгээр хамтран ажиллах чадвар тэдэнд хэзээд үгүй бөгөөд өөрсдөдөө бууж өгөх сөрөг шалтгаан үргэлж хайж байдаг. Чи өөрийнхөө төлөө биш, харин Бурханыг хангалуун байлгахын төлөө бүх зүйлийг хийдэг хүн үнэхээр мөн үү? Чи сэтгэл хөдлөлдөө түшиглэдэггүй, хувийн шилэлт сонголтгүй, харин Бурханы ажлын хэрэгцээг биелүүлдэг хүн үнэхээр мөн үү? “Яагаад хүмүүс Надтай наймаацах гэж үргэлж оролддог юм бэ? Би худалдааны төвийн ерөнхий менежер үү? Хүмүүсийн Надаас шаардсан зүйлийг Би үнэн сэтгэлээсээ биелүүлдэг, гэтэл хүнээс Миний хүссэн зүйл яагаад талаар өнгөрдөг юм бэ?” Яагаад Бурхан тийм зүйлийг хэдэн удаа цувуулан асуудаг вэ? Яагаад Тэр тийнхүү бачимдан дуу алддаг юм бэ? Бурхан хүмүүсээс юу ч олж аваагүй; Түүний хардаг зүйл нь тэдний шилж сонгодог ажил л байдаг. Яагаад Бурхан “гэтэл хүнээс Миний хүссэн зүйл яагаад талаар өнгөрдөг юм бэ?” хэмээн хэлдэг вэ? Өөрсдөөсөө асуу: Сонгож шилэх ямар ч боломжгүй үүрэгт ажлаа хэн эхнээс нь дуустал хийж чаддаг вэ? Өөрсдийн зүрх сэтгэл дэх мэдрэмжийн нөлөөгөөр үйлддэггүй хэн байна вэ? Хүмүүс өөрсдийн зан чанарыг дураар нь тавьж, гурван өдөр загасчлаад дараачийн хоёр өдөр нь тороо орхиж, сул өнгөрөөдөг шиг хийдэг юмандаа хэзээ ч шамддаггүй. Тэд халуун, хүйтнээр ээлжлэн үлээж байдаг: Халуун байх үедээ тэд газар дээрх бүх зүйлийг шатааж чаддаг бөгөөд хүйтэн байх үедээ газар дээрх бүх усыг хөлдөөх чадвартай байдаг. Энэ нь хүний үйл ажиллагаа биш боловч энэ нь хүний байдлын талаарх хамгийн зохистой адилтгал юм. Энэ бодит баримт биш гэж үү? Магадгүй Надад хүмүүсийн талаар “үзэл” байгаа, магадгүй Би тэднийг гүжирдэж байна—гэхдээ ямар ч атугай “Үнэнтэй бол чи дэлхий даяар алхана; үнэнгүй бол хаана ч хүрч чадахгүй.” Хэдий энэ нь хүний мэргэн үг боловч үүнийг энд хэрэглэх нь оновчтой гэж Би бодож байна. Би хүмүүсийн урмыг зориуд хугалж, ажил хэргийг нь үгүйсгэж байгаа юм биш. Би та нартай зарим асуултын талаар зөвлөе: Хэн Бурханы ажлыг өөрсдийн үүрэг хариуцлага мэт үздэг вэ? “Бурханыг л хангалуун байлгаж чадаж байгаа цагт би өөрт байгаа бүхнээ зориулах болно” гэж хэн хэлж чадах вэ? “Бусдыг үл харгалзан би Бурханд хэрэгтэй бүхнийг хийнэ, Бурханы ажлын хугацаа урт ч бай, богино ч бай хамаагүй, би үүргээ биелүүлнэ; Өөрийн ажлыг төгсгөх нь Бурханы хэрэг, энэ нь миний бодох зүйл биш” гэж хэн хэлж чадах вэ? Хэн ийм мэдлэгтэй байх чадвартай вэ? Та нарын юу боддог нь хамаагүй—чи илүү дээр ухвартай байж магадгүй, тэр тохиолдолд Би үг дуугүй найр тавьж, ялагдлаа хүлээнэ—гэсэн ч Бурханы хүсдэг зүйл бол ач санадаггүй чонын

зүрх сэтгэл биш, харин оргилсон чин үнэнч зүрх сэтгэл юм гэдгийг Би та нарт хэлэх ёстой. Та нар энэ “наймаацах” талаар юу мэдэх вэ? Эхнээсээ эцсээ хүртэл та нар “дэлхийгээр аялсан”. Нэг мөчид та нар мөнхийн хавартай “Куньмин” хотод байдаг бөгөөд нүд ирмэхийн зуурт цасаар хучигдсан тэсгим хүйтэн “Өмнөд Туйлд” байдаг. Хэн өөрсдийн амлалтаас хэзээ ч няцаагүй вэ? Бурханы хүсдэг зүйл бол “Үхэх хүртлээ амрахгүй байх” сэтгэл; хүмүүс “урд талын ханыг мөргөх хүртлээ ухарч буцахгүй” сэтгэлтэй байх нь Түүний хүсдэг зүйл. Угаасаа Бурханы санаа зорилго нь хүмүүсийг буруу замаар явуулах биш харин ийм сэтгэлтэй болгох явдал юм. Бурханы хэлдгээр, “Би тэдний өгсөн ‘бэлгүүдийг’ Өөрийн зүйлстэй харьцуулах үед хүмүүс Миний эрхэм нандин байдлыг хоромхон зуур танин мэддэг ба зөвхөн тэр үед л Миний хэмжээлшгүй байдлыг хардаг.” Эдгээр үгийг хэрхэн тайлбарлах вэ? Дээрх үгсийг унших нь чамд зарим нэг мэдлэг өгдөг байх, учир нь Бурхан задлан шинжлэхийн тулд хүний зүрх сэтгэлийг бүхлээр нь гаргадаг бөгөөд тэр үед хүмүүс эдгээр үгийг мэдэж авдаг. Гэхдээ Бурханы үгийн гүн гүнзгий дотоод утга учраас болж хүмүүс хуучин махбодын талаар ойлгохгүй хэвээр үлддэг, учир нь тэд анагаахын их сургуульд сураагүй, мөн археологич ч биш, иймээс тэдэнд энэхүү шинэ нэр томьёо нь ойлгошгүй санагддаг—зөвхөн тэр үед л тэд бага зэрэг буулт хийдэг. Учир нь хүмүүс хуучин махбодын өмнө хүч чадалгүй билээ; хэдийгээр энэ нь догшин араатан шиг биш, мөн хүн төрөлхтнийг цөмийн бөмбөг шиг сөнөөх чадвартай биш боловч тэд үүнийг яахаа мэддэггүй бөгөөд хүч чадалгүй мэт байдаг. Харин Надад бол хуучин бие махбодтой харьцах арга зам байдаг. Хүн сөрөг арга хэмжээний талаар бодох гэж хэзээ ч чармайлт гаргадаггүй нь хүний янз бүрийн этгээд зан Миний нүдний өмнө байнга гялсхийхэд хүргэсэн; Бурханы хэлснээр: “Би тэдэнд Өөрийгөө бүхэлд нь харуулахад Намайг нүдээ бүлтийлгэн ширтэж, Миний өмнө давсан багана мэт хөдөлгөөнгүй зогсдог. Тэдний хачин байдлыг хараад Би инээдээ арай ядан барьдаг. Тэд Надаас юм авахаар гараа сарвайж байгаа учраас Би Өөрийн гарт буй зүйлсийг тэдэнд өгдөг бөгөөд тэд тэдгээрийг дөнгөж төрсөн нярай мэт нандигнан цээжиндээ тэвэрдэг, тэдний хийдэг хөдөлгөөн нь агшин зуурынх л байдаг.” Эдгээр нь хуучин махбодын үйлдэл биш гэж үү? Өнөөдөр хүмүүс ойлголттой болсон хэр нь яагаад болихгүй, харин үргэлжлүүлсээр байдаг юм бэ? Үнэндээ, Бурханы шаардлагын нэг хэсэг нь хүний хүршгүй зүйл биш, гэсэн ч хүмүүс тэдгээрт анхаарал хандуулдаггүй, учир нь “Би хүнийг яаран гэсгээдэггүй. Хүмүүс бие махбодоо үргэлж дураар нь тавьсны шалтгаан энэ юм. Тэд Миний хүслийг ажигладаггүй, харин Миний шүүлтийн ширээний өмнө Намайг дандаа хуурч мэхэлсэн.” Энэ нь хүний биеийн хэмжээ биш гэж үү? Энэ нь Бурхан хэн нэгнээс зориуд өө сэв эрж байгаа биш, харин энэ нь бодит байдал—Бурхан үүнийг тайлбарлах ёстой гэж үү? Бурханы хэлснээр, “Хүмүүсийн ‘итгэл’ ‘гайхан биширмээр’ маш агуу учраас тэр юм.” Энэ шалтгааны улмаас Би Бурханы зохицуулалтыг дуулгавартай дагадаг, иймээс Би энэ талаар ихийг ярихгүй; хүмүүсийн “итгэлийн” улмаас Би үүнийг далимдуулан, Намайг сануулаагүй байхад

чиг үүргээ биелүүлдэг болгохын тулд тэдний итгэлийг ашигладаг. Ингэх нь буруу юу? Энэ нь Бурханд яг хэрэгтэй зүйл биш гэж үү? Магадгүй, ийм үг сонсоод зарим хүнд залхмаар санагдаж болох юм—иймээс Би өөр зүйлийн талаар ярьж, тэдэнд жаахан чөлөө олгоё. Орчлон ертөнц даяарх Бурханы сонгосон бүх хүн гэсгээлт туулах үед, хүний дотоод байдал цэвэрлэгдэх үед хүмүүс гай зовлонгоос зугтсан мэт зүрх сэтгэлдээ нууцхан баярлах болно. Энэ мөчид хүмүүс өөрсдийнхөө төлөө сонголт хийхээ болино, учир нь энэ бол Бурханы сүүлчийн ажлын үеэр хүрэх яг тэр үр нөлөө юм. Түүний алхмууд өнөөдрийг хүртэл ахин дэвшсэнээр Бурханы хөвгүүд болон ардууд бүгд гэсгээлтэд орсон бөгөөд израильчууд ч гэсэн энэ үе шатнаас зугтаж чадахгүй, учир нь хүмүүсийн дотор хольц байдаг тул Бурхан цэвэршүүлэлтийн агуу хайлуулагч зуух руу оруулахаар бүх хүнийг хөтлөх ба энэ нь зайлшгүй зам билээ. Энэ нэгэнт болж өнгөрөхөд хүмүүс үхлээс амилах бөгөөд энэ нь “Долоон Сүнсний айлдваруудад” Бурханы зөгнөсөн яг тэр зүйл юм. Би хүмүүсийг дургүйцүүлэхгүйн тулд энэ талаар дахиж ярихгүй. Бурханы ажил гайхалтай учраас Бурханы амнаас гарсан зөгнөл эцсийн эцэст биелэх ёстой; хүмүүсээс өөрсдийн үзлийн талаар дахин нэг ярихыг Бурхан хүсэхэд тэд мэл гайхдаг бөгөөд хэн ч санаа зовж, түгших учиргүй. Миний хэлснээр, “Миний бүх ажлын дотор хүний гараар хийгдсэн алхам ер нь байсан уу?” Чи эдгээр үгийн мөн чанарыг ойлгож байна уу?

35-Р БҮЛЭГ

Эдүгээ бүх хүн ялгаатай түвшинд гэсгээлтэд орсон. Бурханы хэлснээр “Би хүмүүстэй мөр зэрэгцэн урагш явдаг”. Энэ нь туйлын үнэн боловч хүмүүс энэ санааг бүрэн ойлгож бас л чадахгүй байна. Үүний уршгаар тэдний хийсэн ажлын нэг хэсэг хэрэггүй байсан. Бурхан, “Би тэдний биеийн хэмжээнд нийцүүлэн тэднийг дэмжиж, хангадаг. Хүн бол Миний бүхий л удирдлагын төлөвлөгөөний гол дүр учраас ‘хүн’ хэмээх дүрд тоглогчдод Би илүү их удирдамж өгдөг, ингэснээр тэд уг дүрд үнэн сэтгэлээсээ, чадлынхаа хэрээр тоглоно”, түүнчлэн “…Гэсэн хэдий ч Би тэдний мөс чанарыг шууд шүүмжлэхээс татгалздаг; үүний оронд Би тэднийг тэвчээр, арга дүйгээр залж чиглүүлдэг. Эцсийн эцэст хүмүүс сул дорой бөгөөд ямар ч ажил хийж чаддаггүй” гэж хэлсэн. Бурханы сэтгэлгээ бол энэ: Эцэстээ Тэр энэ бүх хүнийг устгах байлаа ч гэсэн газар дээрх Түүний ажил анхдагч төлөвлөгөөнийх нь дагуу үргэлжилсэн хэвээр байна. Бурхан хэрэггүй ажил хийдэггүй; Бурханы хийдэг бүхэн нь сайн. Петрийн хэлснээр “Бурхан хүмүүсээр тоглоом мэт тоглож байлаа ч гэсэн гомдоллох юм хүмүүст юу байх билээ? Тэдэнд ямар эрх байх юм бэ?” Өнөө үед Бурхан хүн төрөлхтөнтэй биелүүлж буй зүйл энэ биш гэж үү? Хүмүүс үнэхээр ийм үзэл бодолтой байж чадах уу? Өндөр технологитой, одоочлогдсон энэ эринд амьдардаг өнөөдрийн “Петрүүд” чадахгүй байхад хэдэн мянган жилийн өмнө амьдарч байсан Петр ийм зүйл хэлж чадсан бэ? Би түүх урагшилж байна уу, ухарч

байна уу гэдгийг хэлж лав чадахгүй бөгөөд шинжлэх ухаан урагшаа ахисан уу, эсвэл хойшоо алхсан уу гэдэг асуултанд одоогоор хэн ч хариулж чадахгүй. Хүн төрөлхтөн дээр Бурханы хийсэн бүхэн нь тэднийг эерэг болгож, аминд нь боловсрох боломж олгох учиртай байсан юм. Хүмүүс үүнийг ухан ойлгож чадахгүй юу? Чамайг сөрөг байхад хүргэж байгаа бүхэн нь чиний сул тал, энэ нь Сатаны дайрах эмзэг байдлын амин чухал цэг юм. Чамд тодорхой болов уу? Яагаад Бурхан ингэж ярьсан бэ? “Хүн төрөлхтнөөс Би бүр үнэн зүрхнээсээ, чин сэтгэлээсээ гуйж байна. Тэд Миний гуйсан зүйлийг үнэхээр хийж чадахгүй гэж үү?” Эдгээр үг юу гэсэн утгатай вэ? Яагаад Бурхан энэ асуултыг асуусан бэ? Хүн төрөлхтөнд хэтэрхий олон сөрөг тал байдаг бөгөөд хүмүүсийг бүдрүүлэхэд ганцхан сөрөг хүчин зүйл хангалттай гэдгийг энэ нь харуулдаг. Бусад сөрөг нь чамд юу авчрахыг чи бас харж, ойлгож болох юм. Бурханы хийдэг бүхнээ хүн төрөлхтнийг төгс болгохын төлөө хийдэг. Эдгээр үгийг цааш тайлбарлах шаардлагатай юу? Үгүй—Миний үзэхэд, тэгэх хэрэг байхгүй! Хүмүүс Сатанд эзэмдүүлсэн гэж хэлж болох боловч хүмүүс сөрөг байдалд эзэмдүүлсэн гэж хэлэх нь хамаагүй дээр байх болно. Энэ нь хүн төрөлхтний нэг илэрхийлэл, тэдний махан биеийн дайвар юм. Тиймээс бүх хүн өөрийн мэдэлгүй сөрөг байдалд, дараа нь гэсгээлтэд унадаг. Энэ нь хүн төрөлхтөнд Бурханы бэлтгэсэн урхи бөгөөд энэ нь хүмүүсийн хамгийн их зовдог цаг юм. Хүмүүс сөрөг байдалд оршдог учраас гэсгээлтээс зугтах нь тэдэнд хэцүү байдаг. Өнөө үед аливаа зүйл яг ийм байдаг биш үү? Гэхдээ хүмүүс Бурханы дараах үгийг хэрхэн үл ойшоож чадах билээ: “Өнөөдөр Сатан туйлын эрээ цээргүй байна. Өөрийн ажлын гол хэсгийг гайхуулж, Өөрийн агуу хүч чадлыг илчлэхийн тулд Би энэ боломжийг яагаад ашиглахгүй байх билээ?” Би тэдэнд сануулгын хэдэн үг хэлнэ, тэгмэгц чуулганы хүмүүс гэсгээлтэд унадаг. Учир нь Бурханы ажлын хоёр сарын дараа хүмүүс дотроо мөн л бодитой өөрчлөлт хийх хэрэгтэй байна. Тэд Бурханы үгийг зүгээр л оюун санаандаа задлан шинжилдэг хэдий ч тэдний байдал үнэндээ огтхон ч өөрчлөгдөөгүй. Тэд сөрөг хэвээр байна. Ийм болохоор гэсгээлтийн цаг айсуй гэж Бурханыг дурдахад хүмүүс дорхноо энэлэн шаналж, “Би Бурханаар урьдчилан тодорхойлогдсон уу, үгүй юу гэдгээ мэдэхгүй, мөн Би энэ гэсгээлтийн дор бат зогсож чадах эсэхээ мэдэхгүй. Бурхан хүмүүсийг гэсгээхийн тулд ямар арга барил ашиглахыг мэдэхэд бүр ч илүү хэцүү” гэж боддог. Хүмүүс бүгд гэсгээлтээс айдаг мөртөө өөрчлөгдөж чаддаггүй. Тэд зүгээр л чимээгүй зовж шаналдаг, гэхдээ бат зогсож чадахгүй гэж бас айдаг. Гэсгээлтийн сүрдүүлэггүй, үгийн тамлалтгүй нөхцөллд хүмүүс бүгд өөрийн мэдэлгүйгээр гэсгээлт рүү орсон. Тиймээс тэд бүгд бухимдуу, тавгүй байдаг. Үүнийг “юу тарина, түүнийгээ хураана” гэж хэлдэг, учир нь хүмүүс Бурханы ажлыг огтхон ч ойлгодоггүй. Үнэндээ, Бурхан энэ хүмүүст цаашид дахин үгээ гарздах дургүй байна; Бурхан жинхэнэ гэсгээлт биш, харин тэдэнтэй харьцах өөр арга хэрэглэх болсон юм шиг байна. Энэ нь хүн нэг дэгдээхий барьж аваад эм тахиа юу, эсвэл азарган тахиа юу гэдгийг харахаар дээш нь өргөдөгтэй адил; энэ нь нэг их чухал хэрэг мэт санагдахгүй байж болох

боловч бяцхан дэгдээхий маш их айж, эзэн нь алж идэх нь гэж айсан мэтээр гараас нь мултрахын тулд тэмцэх болно. Учир нь дэгдээхий өөрийнхөө талаар ямар ч мэдлэггүй байдаг. Хэдхэн унц жинтэй дэгдээхийг хүн яагаад алж идэх юм бэ? Ямар ч утгагүй юм болох биш үү? Энэ нь яг л Бурханы хэлсэн шиг байдаг: “Тэгвэл яагаад хүмүүс Надаас байнга зайлсхийдэг юм бэ? Би тэднийг баригдмагцаа алагдах ангаахай шиг үзэж хандана гээд тэр үү?” Тиймээс хүний зовлон бүгд “амь бие хайргүй” зүтгэл бөгөөд үүнийг ямар ч хэрэггүй төлөөс гэж хэлж болно. Хүмүүс өөрсдийгөө мэддэггүй учраас айдаг; үүний үр дүнд тэд амь дүйж чаддаггүй. Энэ бол хүн төрөлхтний сул тал юм. Бурханы хэлсэн “Эцэст нь хүмүүст өөрсдийг нь мэдүүл. Энэ бол Миний эцсийн зорилго” хэмээх үг үеэ өнгөрөөсөн үү? Хэн өөрийгөө үнэхээр мэддэг вэ? Хэрвээ хүн өөрийгөө мэддэггүй бол гэсгээгдэх эрхийг тэдэнд юу өгдөг вэ? Жишээ нь, хургыг аваад үз. Хэрвээ тэд хонь болж өсөөгүй байгаа бол тэднийг нядалж яаж болох юм бэ? Жимслэдэггүй модыг хүмүүс хэрхэн таашаах юм бэ? Хүн бүхэн “урьдчилан сэргийлэх тарилгад” хэтэрхий их ач холбогдол өгдөг. Тиймээс хүмүүс бүгд мацаг барих ажил хийж байгаа ба тэгээд өлсгөлөн байдаг. Энэ нь хүн юу тарина, түүнийгээ хураадаг, өөрсдийгөө сүйрүүлдгийн жишээ, харин Бурханы харгислал, хэрцгий явдал биш юм. Хэрвээ нэг өдөр хүмүүс гэнэт өөрсдийгөө мэдэж, Бурханы өмнө айсандаа дагжин чичирвэл Бурхан тэднийг гэсгээж эхэлнэ. Зөвхөн ийм байдлаар хүмүүс зовлон бэрхшээлийг зүрх сэтгэл, үг яриандаа дуулгавартайгаар дуртайяа хүлээж авна. Гэвч өнөөдрийн хувьд ямар вэ? Хүмүүс бүгд хүсэл зоригийнхоо эсрэг гэсгээгддэг ба хүүхдүүдээр хоол хийлгэж байгаа мэт байдаг. Тийм болохоор тавгүй санагдахгүй байж яаж болох юм бэ? Хүн бүхэн “За яах вэ! Нэгэнт гэсгээгдэж байгаа болохоор би толгойгоо бөхийн, буруугаа хүлээж бас болно байх! Би юу хийж чадах юм бэ? Би уйлж байгаа ч гэсэн би Бурханыг хангалуун байлгах ёстой, иймээс би юу хийж чадах юм бэ? Сайн ч бай, муу ч бай энэ бол миний одоо явж байгаа зам. За яах вэ! Зүгээр л миний аз дутаж гэж бодъё!” хэмээн боддог. Хүмүүс ингэж боддоггүй гэж үү?

Бурханы хэлснээр, “Хүн төрөлхтөн томоотой байдаг; Намайг хэн ч эсэргүүцэж зүрхэлдэггүй. Бүгд Миний удирдамж дор, Миний даалгасан үүргийг биелүүлж байна” Ганц ч хүн сайн дурааараа гэсгээгдэхгүй ба цаашлаад энэ гэсгээлт Бурханаас ирсэн, учир нь хүмүүс бүгд үймээн самуун, эмх замбараагүй байдалд байснаас тааваараа амьдрахыг хүсдэг гэдгийг харуулахад энэ хангалттай. Бурхан “Үхлээс айдаггүй хэн байна вэ? Хүмүүс үнэхээр биеэ золиосолж чадах уу?” гэсэн. Энэ бол туйлын зөв; хүн бүхэн мэдээж уур, эсвэл цөхрөлд автаагүй л бол үхэхээс айдаг. Энэ нь хүний мөн чанар бөгөөд энэ нь шийдэхэд дэндүү хэцүү. Өнөөдөр Бурхан яг энэ бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд ирсэн. Хүмүүс бүгд хүч чадалгүй, иймээс Бурхан тэдний ийм өвчнийг эмчлүүлж болох нарийн мэргэжлийн эмнэлэг тэдний дунд зориуд байгуулсан. Хүмүүс өөрсдийгөө энэхүү өвчний урхинаас чөлөөлж чадахгүй, ийм учраас тэд бүгд маш их сэтгэлийн зовуурьтай, амны үрэвсэлтэй, дүүрэнгэ гэдэстэй хөөсөн байдаг. Цаг хугацаа өнгөрөх тусам хэвлийнх нь хийн хэмжээ өсөж, даралтыг

нь ихэсгээд эцэстээ гэдэс нь хагарч, тэд бүгд үхнэ. Тиймээс Бурхан тэгээд хүний энэ ноцтой өвчнийг эмчилсэн, учир нь хүн бүр үхсэн байна. Хүний өвчин эдгэрсэн нь энэ биш үү? Бурхан энэ ажлыг хийхийн тулд зориуд ирсэн. Хүмүүс үхлээс маш их айдаг учраас энэ ажлыг хүмүүстэй хамт хийхийн тулд Бурхан Өөрөө ирсэн; тэдний зориг тун бага учраас Тэр тэдэнд эхлээд үзүүлэн харуулсан. Бурханы урьдын жишээг харсныхаа дараа л хүмүүс дуулгавартай байхад бэлэн байна. Энэ шалтгаанаар Бурхан "Хэн ч Миний ажлыг хийж чадахгүй учраас Сатантай үхэх сэхээхээ үзэх тулалдаанд орохын тулд Би тулааны талбарт биечлэн хөл тавьсан юм" гэж хэлсэн. Энэ бол шийдвэрлэх тулаан, иймээс нэг бол загас үхнэ, эсвэл тор урагдана. Энэ бол гарцаагүй. Сүнс эцэстээ ялах учраас махан биеийг гарцаагүй үхэл авна. Та нар үүний цаад утгыг ойлгож байна уу? Гэхдээ дэндүү бүү эмзэглэ. Дээрх өгүүлбэр энгийн байж магадгүй, эсвэл адармаатай ч байж магадгүй. Ямар ч атугай хүмүүс үүнийг ойлгож чадахгүй—Энэ бол гарцаагүй. Зовлон дунд хүмүүс Бурханы үгийн цэвэршүүлэлтийг хүлээн авч чаддаг, хүн үүнийг зол заяа гэж ч магадгүй, эсвэл гай барцад гэж ч магадгүй. Гэхдээ Бурханы санаа зорилго бол эцсийн эцэст зөв гэдгийг Би хүн бүхэнд мөн л сануулна—энэ нь үргэлж өөрийнхөө төлөө төлөвлөгөө зохиож, зохицуулалт хийж байдаг хүмүүсийн санаа зорилготой адилгүй. Энэ маш тодорхой байх хэрэгтэй; эцэс төгсгөлгүй эргэцүүлэлд бүү авт. Энэ нь яг хүний сул тал биш гэж үү? Тэд бүгд ийм байдаг; Бурханыг асар их хайрлахын оронд өөрсдийгөө ихэд хайрладаг. Тэр бол хүнд атаархдаг Бурхан учраас тэдэнд үргэлж шаардлага тавьдаг. Хүмүүс өөрсдийгөө хэдий чинээ их хайрлах тусм Өөрийг нь хайрлахыг Бурхан тэднээс улам их шаарддаг ба тэдэнд тавих Түүний шаардлагууд улам хатуу болдог. Энэ нь Бурхан хүмүүсээр санаатай тохуурхаж байх мэт байдаг. Хэрвээ хүмүүс Түүнийг үнэхээр хайрладаг бол Тэр тэднийг тоодоггүй мэт. Үүний улмаас хүмүүс хуйхаа маажиж, гүн бодолд автдаг. Энэ нь Бурханы зан чанарын хүүрнэл, ганц хоёр зүйлийг товч дурдсан төдий юм. Энэ бол Бурханы хүсэл. Хүмүүсийг мэд гэж Бурханы шаарддаг зүйл энэ бөгөөд энэ нь зайлшгүй амин чухал. Энэ бол шинэ хичээл бөгөөд хүмүүс амжилтад хүрч, шинэ ахиц гаргахын тулд шаргуу ажиллах ёстой. Та нар үүнийг ойлгов уу? Би энэ сэдвээр өөр юм хэлэх хэрэгтэй байна уу?

Өмнөх эринүүдийн тухай Бурхан хэлсэн нь: "ганц ч хүн Надаар сонгогдоогүй; Миний чимээгүй мэдлэг хүн бүхнийг няцаасан. Учир нь, өнгөрсөн үеийн хүмүүс Надад онцгойлон үйлчлээгүй; тиймээс хариуд нь Би тэднийг онцгойлон хайрлаагүй. Тэд Сатаны 'бэлгүүдийг' авсан ба дараа нь тэдгээрийг Надад хээвнэг барьсан. Энэ нь Миний эсрэг доромжлол биш байсан гэж үү?" Эдгээр үгийг хэрхэн тайлбарлах вэ? Бурханы хэлснээр: "Билиг авьяас бүхэн Сатанаас гаралтай." Өнгөрсөн үеүдийн элч нар, эш үзүүлэгчид өөрсдийн ажлыг хийхдээ өөрсдийн билиг авьяаст бүрэн түшиглэдэг байсан ба эрин үеүдийн турш Бурхан Өөрийн ажлыг явуулахдаа тэдний билиг авьяасыг ашигласан. Ийм учраас билиг авьяастай бүх хүний үйлчлэл Сатанаас ирдэг гэж хэлдэг. Гэсэн хэдий ч Бурханы мэргэн ухаанаас үүдэн "Би Сатаны ов мэхийг Өөрийн товойлгогч болгон ашигладаг." Тиймээс авьяас билигтэй

хүмүүсийн үйлчлэлийг Бурхан “Сатаны бэлэг” гэж нэрлэсэн бөгөөд тэдгээр нь Сатанд харьяалагддаг учраас Бурхан энэ үйлдлийг “доромжлол” гэж нэрлэдэг. Энэ нь хүмүүсийн эсрэг ор үндэсгүй буруушаалт биш; харин ч энэ нь ултай үндэслэл бүхий, зохистой тайлбар юм. Тиймээс “Би Өөрийн зэвүүцлийг харуулаагүй; оронд нь Би эдгээр ‘бэлгийг’ Өөрийн удирдлагын эд материалуудад нэмснээр тэдний арга мэхийг Өөртөө ашигтайгаар эргүүлсэн. Хожим тэднийг машин боловсруулсны дараа Би үүссэн бүх хог хаягдлыг шатааж орхино.” Энэ бол Бурханы ажлын их гайхамшиг юм. Энэ зүйл нь хүний үзэлтэй хамгийн бага нийцдэг, учир нь хаан болж хаанчилдаг хүмүүс билиг авьяастай хүмүүс биш, эсвэл тэд бол Бурханы хайртай авьяас билиггүй хүмүүс юм гэж хэн ч бодохгүй. Витнес Ли болон Ватчман Нигийн санаа бодол буюу найдвар нь бүгд үнс нурам болсон ба өнөө үеийн билиг авьяаст хүмүүс ч ялгаагүй гэдгийг харж болно. Одоо Бурхан энэ ажлыг эхэлчихсэн бөгөөд Түүний ажилд товойлгогч болон үйлчилдэг хүмүүс дэх Ариун Сүнсний бүх ажлыг Тэр аажмаар буцаан авч байна. Бурханы ажил бүрмөсөн дуусах үед энэ хүмүүс бүгд өөрсдийн анхдагч байрандаа буцаж очно. Гэсэн хэдий ч Миний үгээс болж болчимгүй аашлахгүй бай гэж Би хүмүүсийг ятгадаг. Та нар Бурханы ажилд саад болохгүйн тулд юмсын жам ёсыг Бурханы ажлын алхмуудтай нийцүүлэн дагах хэрэгтэй. Та нар энэ зүйлийг ойлгож байна уу? Учир нь энэ бол Бурханы ажлын алхам, арга барил билээ. Бурхан эдгээр “бэлгийг” “бэлэн бүтээгдэхүүн” болгон “боловсруулах” үед Түүний бүх санаа зорилго илэрхий болох ба Түүнд үйлчлэл үзүүлдэг бэлгүүд бүгд таягдуулна; гэвч Бурхан таашаах бэлэн бүтээгдэхүүнтэй болох юм. Та нар үүнийг ойлгож байна уу? Бурханы хүсдэг зүйл нь бэлэн бүтээгдэхүүн болохоос хүмүүсийн өргөн барьдаг элбэг дэлбэг бэлэг биш. Хүн бүхэн зохих байраа эзэлсэн үед л, өөрөөр хэлбэл, Бурхан анхдагч байр сууриндаа эргэн очиж, диавол ч гэсэн суудалдаа сууж, мөн тэнгэрэлчүүд нэг нь ч ялгаагүй тэгсэн үед—зөвхөн тэр үед л Бурханы царайд баярын инээмсэглэл тодорно, учир нь Түүний санаа зорилго бүтэж, Түүний зорилт биелсэн байх юм. Бурхан цаашид “диаволоос” “тусламж” хүсэхээ болино, учир нь Бурханы санаа зорилго хүмүүст илэн далангүй илчлэгдсэн байх ба дахин хэзээ ч тэдгээрийг хүмүүсээр дамжуулахгүй. Энэ үед хүний махан бие сүнстэй нь нэг болно. Энэ бол хүмүүст Бурханы харуулдаг зүйл; энэ нь сүнс, сэтгэл, бие гурвын эцсийн хүрэх газар юм. Энэ нь “хүний” тухай анхдагч утга санааны дүгнэлт билээ. Үүнийг нарийвчлан судалж шинжлэх хэрэггүй; энэ талаар ганц хоёр зүйлийг мэдэхэд хангалттай. Та нар ойлгов уу?

36-Р БҮЛЭГ

Бурхан одоо хүнийг гэсгээж эхэлсэн гэдэг боловч энэхүү гэсгээлтийн анхдагч санаа зорилго нь хүнд тохиолдсон эсэхийг хэн ч баттай хэлж, тодорхой хариу өгч чаддаггүй. Бурхан, “Хүн Миний гэсгээлтээс хэзээ ч, юу ч олж илрүүлээгүй, учир нь

тэр хүзүүнд нь угласан буулгыг хоёр гараараа зуурахаас өөр юм хийдэггүй ба дайснаа ажиглаж байгаа юм шиг Надаас нүд салгадаггүй—зөвхөн энэ мөчид л Би түүний хэчнээн эцэнхий болохыг нь хардаг. Үүний улмаас шалгалтуудын дунд ер нь хэн ч бат зогсоогүй гэж Би хэлдэг юм" гэсэн. Хүнд хараахан тохиолдоогүй байгаа гэсгээлтийн баримтуудын тухай Бурхан түүнд хэлдэг бөгөөд юу ч орхилгүй асар их нарийвчлан хэлдэг. Хүмүүс гэсгээлтэд орсон бөгөөд үнэхээр бат зогсож чадахгүй юм шиг байдаг. Бурхан хүний муухай дүрийн талаар тод томруун, бодит дүрслэл өгдөг. Иймээс хүмүүст дарамтан дор байгаа мэт санагддаг: Хүн шалгалтуудын дунд хэзээ ч бат зогсоогүй гэж Бурхан хэлсэн тул Би яаж дэлхийн дээд амжилтыг эвдэж, тогтсон заншлыг үл харгалзан хүлээн зөвшөөрөгдөх нэгэн байж чадах юм бэ? Энэ мөчид тэд эргэцүүлж эхэлдэг. Үнэн хэрэгтээ энэ нь яг "Би тэднийг мөхлийн замд аваачсан гэж үү?" хэмээн Бурханы хэлсэнтэй адил байдаг. Үнэндээ Бурхан бүх хүнийг мөхлийн замд аваачсан ба иймээс өөрсдийн ухамсартаа хүмүүс Бурхан бол харгис, хэрцгий гэж үргэлж боддог. Бурхан бүх хүнийг дэлхий ертөнцийн гаслангийн далайгаас шүүрдэж гаргасан, үүний дараа "ямар нэгэн осол эндлээс сэргийлэхийн тулд Би баригдсан бүх 'загасыг' алсан, үүний дараа загас дуулгавартай болсон бөгөөд өчүүхэн төдий ч гомдол гаргаагүй". Энэ бодит баримт биш гэж үү? Бурхан бүх хүнийг үхлийн гашуун далайгаас үхлийн өөр нэг ёроолгүй ангал руу татсан, Тэр тэднийг бүгдийг нь "зандалчны хавтан" руу чирсэн, Тэр тэднийг мөхлийн зам руу албадан оруулсан—Тэр Бурханы өөр хөвгүүд болон ардуудыг яагаад ингэдэггүй вэ? Агуу улаан лууны оронд ийм ажил хийж байгаагийн санаа зорилго юу вэ? Яагаад Бурханы гар ийм "хорлонтой" байдаг юм бэ? "Надад хүн хэрэгтэй байх үед тэр үргэлж нуугдсан байдаг. Тэрээр хэзээ ч гайхмаар дүр зураг үзээгүй юм шиг, хөдөө төрөөд хотын хэрэг явдлын талаар юу ч мэддэггүй юм шиг байдагт" нь гайхах хэрэггүй. Үнэн хэрэгтээ, хүмүүс дотроо: "Ийм юм хийхдээ Бурхан юу төлөвлөж байна? Тэр биднийг хөнөөж байгаа юм биш үү? Ямар учиртай юм бэ? Түүний ажлын алхмууд яагаад хурдан угсруулан ирдэг, яагаад Тэр бидэнд өчүүхэн төдий ч зөөлөн ханддаггүй юм бэ?" Гэсэн ч хүмүүс үүнийг хэлж зүрхэлдэггүй бөгөөд Бурханы үг тэднийг тийм бодлоо хаяхад хүргэж, цааш бодох боломжийг нь үгүй болгодог учраас тэд тиймэрхүү бодлуудаа хойш тавихаас өөр аргагүй байдаг. Бурхан зүгээр л хүний бүх үзлийг илчилдэг бөгөөд иймээс хүмүүс өөрсдийн үзлийг хүчээр дарж, гарч ирэх боломж олгодоггүй. Эдгээр хүмүүс бол агуу улаан лууны үр удам гэдгийг өмнө нь хэлсэн. Үнэн хэрэгтээ, тодорхой хэлэх юм бол тэд агуу улаан лууны биелэл юм. Бурхан тэднийг мөхлийн замд албадан аваачиж, хядах үед—эргэлзэх юмгүйгээр—агуу улаан лууны сүнс тэдэн дотор ажиллах боломжгүй болдог. Ийм байдлаар хүмүүс мөхлийн зам руу алхах үе нь бас агуу улаан лууны үхэх үе юм. Бурханы "агуу нигүүлслийг" хариулахаар үхлийг ашиглах явдал гэж үүнийг хэлж болно—энэ нь агуу улаан лууны улс орон дундах Бурханы ажлын зорилго билээ. Хүмүүс амиа золиослоход бэлэн байх үед бүх зүйл ялихгүй болж, хэн ч тэднийг дийлж чадахгүй. Аминаас илүү чухал зүйл юу байх юм бэ? Тиймээс

Сатан хүмүүст өөр юу ч хийх чадваргүй болдог ба тэр хүнийг яаж ч чадахгүй. Хэдийгээр “махан биеийн” тодорхойлолтод махан бие Сатанаар завхруулагдсан гэдэг боловч хэрвээ хүмүүс үнэхээр өөрсдийгөө зориулж, Сатанаар жолоодуулахгүй бол хэн ч тэднийг дийлж чадахгүй—энэ мөчид махан бие өөр нэг чиг үүргээ гүйцэтгэж, Бурханы Сүнсний удирдамжийг албан ёсоор хүлээн авч эхлэх болно. Энэ бол шаардлагатай үйл явц бөгөөд энэ нь алхам алхмаар тохиолдох ёстой; эс бөгөөс Бурхан зөрүүд махан биед ажиллах ямар ч аргагүй байх байсан юм. Бурханы мэргэн ухаан ийм билээ. Ийм маягаар бүх хүн өөрийн мэдэлгүй өнөөдрийн нөхцөл байдалд орсон юм. Хүнийг “мөхлийн зам” руу хөтөлсөн нэгэн нь Бурхан биш гэж үү? Энэ нь хүний нээсэн шинэ зам байж болох уу? Та нарын туршлагаас харахад Бурхан та нарт туйлын харгис арга хэрэглэдэг бололтой бөгөөд үүнээс Бурханы зөвт байдлыг харж болно. Та нар яаж магтаал өргөхгүй байж чадах юм бэ? Бурханы та нарт хийдэг зүйл нь Бурханы зөвт зан чанарыг харах боломжийг хүмүүст олгодог; үүнд та нар Бурханыг бахдвал зохих бус уу? Өнөөдөр, хуучин эрин оршсоор байж, шинэ эрин хараахан бий болоогүй замын уулзвар дээр та нар Бурханд хэрхэн гэрчлэл хийх юм бэ? Ийм ноцтой асуудлыг чамбай авч үзүүштэй биш үү? Та нар бусад, холбоо хамааралгүй хэрэг явдлуудыг тунгааж боддог хэвээр үү? “Хэдийгээр хүмүүс нэгэнтээ ‘Ойлголт мандтугай’ хэмээн хашхирсан боловч ‘ойлголт’ хэмээх үгийг задлан шинжлэхэд хэн ч их цаг зарцуулаагүй бөгөөд хүмүүст Намайг хайрлах хүсэл байхгүй гэдгийг энэ нь харуулдаг” гэж Бурхан яагаад хэлсэн бэ? Хэрвээ Бурхан ийм зүйл хэлээгүй бол та нар Бурханы зүрх сэтгэлийг өөрсдийнхөө хүслээр ойлгох гэж оролдохгүй байсан гэж үү?

Сүүлийн үед зарим хүн Бурхан бие махбод болсны зорилго болон ач холбогдлын талаар бага зэрэг мэдэж авсан байж магадгүй, гэхдээ хэрвээ Бурхан хүнтэй илэн далангүй яриагүй бол хэн ч Бурхан бие махбодтой болсны зорилго, ач холбогдлыг тааж чадахгүй байсан гэдгийг Би баттай хэлж чадна. Энэ нь маргаангүй юм. Энэ та нарт бас л ойлгомжгүй байна уу? Хүмүүст Бурханы хийдэг бүхэн нь Түүний удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм—гэтэл тэд Бурханы хүслийг нарийн зөв ухаарах чадваргүй байдаг. Энэ нь хүний дутагдал боловч Бурхан хүмүүсээс ямар нэгэн зүйл хийх чадвартай байхыг шаарддаггүй ба Тэр зүгээр л тэдэнд “эмчийн сэрэмжлүүлгийг” сонсгодог. Энэ нь Бурханы шаардлага юм. Тэрээр бүх хүнд жинхэнэ хүний амьдралыг мэдүүлдэг, учир нь “тэдний зүрх сэтгэлд ‘хүний амьдрал’ хэмээх үг байхгүй, тэдгээрийг тоодоггүй ба Би нэг үглээ эмгэн болсон мэт Миний үгээс зүгээр л залхдаг.” Хүмүүсийн үзэхэд, Бурханы үг өдөр тутмын багаж хэрэгсэлтэй адилхан бөгөөд тэдгээрийг чухал гэж огт үздэггүй. Тиймээс хүмүүс Бурханы үгийг хэрэгжүүлж чаддаггүй—тэд үнэнийг мэддэг боловч хэрэгжүүлдэггүй олхиогүй заяа муутнууд болсон. Тиймээс хүний энэхүү алдаа урт хугацаанд Бурханы зэвүүцлийг төрүүлэхэд дангаараа хангалттай, иймээс Тэр хүмүүс Түүний үгэнд ямар ч анхаарал хандуулдаггүй гэдгийг олон удаа хэлсэн билээ. Гэсэн хэдий

ч өөрсдийн үзлээр хүмүүс дараах зүйлийг боддог: “Бид өдөр бүр Бурханы үгийг судалж, шинжилдэг байтал биднийг анхаарал хандуулдаггүй гэж яаж болох юм бэ? Ингэх нь бидэнд шударга бус байгаа хэрэг биш үү?” Харин Би чамд бага зэрэг задалж өгье—хүмүүсийн царай улайх болно. Бурханы үгийг унших үедээ тэд толгой дохиж, эзнийхээ үгэнд шарваганан эрхлэх бээжин хав шиг зусардан бөхөлздөг. Тийнхүү энэ мөчид хүмүүс хэрэггүйгээ мэдэрч, хацрыг нь даган нулимс урсдаг, тэд гэмшиж, шинээр эхлэхийг хүсэж байгаа мэт байдаг—гэхдээ нэгэнт энэ цаг өнгөрчихвөл тэдний бүрэг номой байдал даруй алга болж, чоно мэт араатны байдлаар солигддог; Бурханы үгийг нэг тийш тавиад өөрсдийнх нь хувийн ажил явдал тэргүүнд, Бурханы хэрэг явдал сүүлд орно гэж үргэлж итгэдэг бөгөөд эдгээр үйлдлийнхээ улмаас тэд Бурханы үгийг хэрэгжүүлж хэзээ ч чаддаггүй. Баримтууд гарч ирэхэд тэд тохойгоо ёрдойлгодог[a]—энэ нь өөрсдийнхөө хүмүүсээс урвах явдал бөгөөд—тэд “амин зуулгаа Надад найдчихаад ‘өөр замаар гүйдэг’” гэж Бурханы хэлдэгт гайхах юмгүй. Бурханы үгэнд өчүүхэн төдий ч худал хуурмаг байдаггүй, тэдгээр нь бүхэлдээ үнэн бөгөөд өчүүхэн төдий ч хэтрүүлэг агуулдаггүй гэдгийг зөвхөн үүнээс харж болох ч тэдгээрийг ямар нэг хэмжээгээр дутуу үнэлсэн юм шиг санагддаг, учир нь хүний биеийн хэмжээ хэтэрхий жаахан, тэдгээрийг дааж чадахгүй. Бурханы үг аль хэдийн хүний зүйлсийн талаар гадна дотногүй тов тодорхой дүрслэл өгсөн; тэдгээр нь тэднийг туйлын тодорхой сийлж, Сатаны анхдагч нүүр царайтай яг адилхан байдлыг нь хурцаар дүрсэлсэн. Одоогийн энэ үе шатанд л хүмүүс бүхнийг хараахан тодорхой харахгүй байгаа юм, тиймээс тэд өөрсдийгөө мэдэж аваагүй гэж хэлсэн. Үүний учир энэ хичээлийг үргэлжлүүлэх ёстой; зогсоож болохгүй гэж Би хэлдэг. Хүмүүс өөрсдийгөө мэдэж авах үе нь Бурхан алдрыг олж авах үе байх болно. Үүнийг ойлгоход амархан—Би дэлгэрүүлж ярих хэрэггүй. Гэвч Би та нарт нэг зүйлийг сануулна, гэхдээ эхлээд Бурханы энэ үгсийг унших ёстой: “Өнөө үед хүмүүс Намайг хэзээ ч эрхэмлээгүй, тэдний зүрх сэтгэлд Би зай эзэлдэггүй. Тэд ирж буй зовлонгийн өдрүүдэд Намайг гэсэн жинхэнэ хайрыг харуулж чадах уу?” Эдгээр үгийн утга нь юу вэ? Гэсгээлт хүнд хараахан тохиолдоогүй байна гэж Бурхан хэлж байгаа нь “өөрийгөө мэдэх” гэдэг үгэнд дотоод утга учир байдгийг харуулдаг—чи үүнийг ойлгов уу? Бэрхшээл, цэвэршүүлэлт туулахгүйгээр хүмүүс яаж өөрсдийгөө мэдэж чадах юм бэ? Эдгээр нь дэмий хоосон үг биш гэж үү? Чи Бурханы хэлсэн бүхэнд үнэхээр итгэдэг үү? Чи Бурханы үгийг ялган салгаж чаддаг уу? Яагаад Бурхан “Хүний үйлдлийг харахад Миний цорын ганц сонголт бол орхин явах юм” гэх мэт зүйлийг дахин дахин хэлж, мөн “Зөвхөн уулс нурж, газар цууран хагарахад л хүмүүс Миний үгийн талаар бодож, зөвхөн тэр үед л тэд зүүднээсээ сэрдэг боловч тэр цаг аль хэдийн ирсэн

[a] “Тохойгоо ёрдойлгох” гэдэг нь Хятадын хэлц үг бөгөөд энэ нь хүн өөрийнхөө ойр дотно хүмүүсийг, жишээлбэл, эцэг эх, үр хүүхэд, хамаатан садан, эсвэл ах дүүсээ золиослон бусдад туслах гэсэн утгатай.

байдаг ба тэд асар их үерт автаж, цогцсууд нь усны гадарга дээр хөвж байдаг” гэж хэлдэг вэ? Яагаад Бурхан “хүмүүс Миний үгийг дуулгавартай дагадаг” гэж хэлэлгүй, харин “хүмүүс боддог” гэдэг вэ? Уулс нурж, газар цууран хагарна гэж үнэн үү? Хүмүүс ийм үгийг тоодоггүй, чихнийхээ хажуугаар өнгөрүүлдэг, иймээс тэд Бурханы үгээс ихээхэн “бэрхшээл” амсдаг. Учир нь, тэд хэтэрхий хайхрамжгүй. Хүний энэхүү дутагдлын улмаас Бурхан “Би, нулимсны суваггүй энэ ‘гажиг этгээд’ нь хүний төлөө их нулимс урсгасан юм. Гэсэн хэдий ч хүн энэ талаар юу ч мэддэггүй” гэсэн. Хүмүүс Бурханы үгэнд анхаарал хандуулдаггүй учраас Бурхан тэдэнд сануулж, тэдний “тусламжийг” авахын тулд энэ аргыг ашигладаг.

Одоогоор Би дэлхийн хөгжлийн талаар зөгнөхгүй, харин хүний хувь заяаны зарим нэг зүйлийг урьдчилан хэлнэ. Би хүмүүст өөрсдийг нь мэдүүлээгүй бил үү? Үүнийг хэрхэн тайлбарлах вэ? Хүмүүс өөрсдийгөө хэрхэн мэдэх ёстой вэ? Бурхан хүмүүсийг амьдрал, үхлийн хооронд эргэлдтэл нь “тарчилгах” үед тэд хүний амьдралын утга учрын талаар бага зэрэг ойлгож эхэлдэг бөгөөд тэд хүний бүхий л амьдралыг зүүднээс өөр юу ч биш гэж итгэн хүний амьдралаас залхдаг. Хүний амьдрал бол зовлон шаналгааны амьдрал, тэд ерөөсөө юунд ч хүрэлгүй үхэх бөгөөд амьдрал нь утгагүй, үнэ цэнэгүй гэж тэд итгэдэг. Хүний амьдрал бол ердөө л зүүд, уй гашуу, аз жаргал ээлжилдэг зүүд юм. Өнөөдөр хүмүүс Бурханы төлөө амьдардаг боловч тэд хүний ертөнцөд амьдардаг учраас өдөр тутмын амьдрал нь хий хоосон агаад үнэ цэнэгүй хэвээр үлдэж, Бурханы таалал бол ердөө л өнгөрөн одох тав тух юм гэдгийг бүх хүнд мэдүүлдэг—гэхдээ хэрвээ тэд Бурханыг таалахгүй үедээ Бурханд итгэдэг ч гэсэн мөн л махан биед амьдарч байвал ямар хэрэгтэй юм бэ? Махан биед бүх зүйл хүний хувьд хий хоосон. Хүний амьдралын аз, эзийг туулаад өтөл насандаа очиход хүний үс цагаан болж, нүүр нь үрчлээгээр дүүрч, гар нь эвэршдэг. Хэдийгээр их төлөөс төлсөн боловч тэр үнэн хэрэгтээ юу ч олж аваагүй. Тиймээс Миний үг нэг алхам ахидаг: Махан биед амьдардаг хүмүүсийн хувьд бүх зүйл хий хоосон байдаг. Энэ эргэлзээгүй бөгөөд үүнийг нарийвчлан шалгах хэрэг чамд байхгүй. Энэ бол Бурханы дахин дахин ярьсан хүний амьдралын анхдагч нүүр царай юм. Бурхан хүний сул талын улмаас эдгээр үгээс зайлсхийдэггүй, харин зүгээр л анхдагч төлөвлөгөөнийхөө дагуу үйлддэг. Зарим үг нь хүмүүсийг дэмжлэг болон ойлголтоор хангадаг байх, зарим нь яг эсрэгээр нь хийж, хүмүүсийг зориуд үхлийн орчинд амьдрахад хүргэдэг байх—яг үүний улмаас л тэд зовдог юм. Тиймээс Бурхан хүмүүсийг зориуд будилуулахын тулд “хоосон хотын стратеги”[б] дэвшүүлдэг байх, гэвч тэд үүнийг огтхон ч ойлгож чаддаггүй бөгөөд мэдэхгүй хэвээр үлддэг. Гэсэн ч бүх зүйл Бурханы гарт байдаг ба хэдийгээр хүмүүс үүнийг мэддэг ч гэсэн яаж үүнээс хамгаалж чадах юм бэ? Тиймд хэн ч гэсгээлтийн заналхийллээс зугтааж чадахгүй—тэд юу хийж чадах юм бэ? Тэд

[б] “Хоосон хотын стратеги” гэж эртний Хятадын 36 стратегийн 32 дахь нь юм. Дайснаа мэхлэхийн тулд бэлтгэл муутайгаа нууж, хоосон сүр үзүүлэх арга энэ стратегид багтана.

Бурханы зохицуулалтад захирагдаж л чадна—энэ нь Бурхан тэднийг барьж аваад явуулахгүй байгаагаас болоогүй гэж үү? Зөвхөн Бурханы сүрдүүлэг дор бүх хүн байгалийн жамыг дагаж чадна—тийм биш гэж үү? Бурханы зохицуулалт байгаагүй бол хүмүүс ялагдлаа яаж сайн дураараа хүлээх юм бэ? Тэр ч инээдтэй юм болохгүй гэж үү? Хэдийгээр хүний амьдрал хий хоосон боловч амьдрал нь тав тухтай байх үед хэн хүний ертөнцийг чимээгүйхэн орхиж, Бурханыг хангалуун байлгах гэж оролдохыг хүсэх юм бэ? Хүмүүс арчаагүй байдалд үхдэг—хүссэн бүхэн нь байдаг элбэг дэлбэг байдал дунд үхсэн хэн байна вэ? Тэнгэрээс бууж ирсэн “од” л үүнээс ангид байна. Түүний эдэлсэн гуравдагч тэнгэрийн амьдралтай харьцуулахад газар дээрх амьдрал нь үхэгсдийн оронд амьдрахтай адилхан—зөвхөн тийм нөхцөл байдалд тэр үхэхэд бэлэн байж магад. Гэсэн ч өнөөдөр хэн тэнгэрийн од юм бэ? Би ч гэсэн энэ талаар “тодорхой мэдэхгүй” байна. Бүгдээрээ эрж хайгаад олж чадах нь уу, үзье. Хэрвээ тэр олдвол Би, Миний дээрх үгийн дагуу үйлдэхэд бэлэн эсэхийг нь асуухад Надад туслахыг хүмүүсээс гуйя. Гэсэн ч та нарт бүгдэд нь өгөх анхааруулга Надад байна: Та нарын хэн нь ч “баатрын” дүр эсгэж, сайн дураараа үхэхээр шийдэх ёсгүй, та нар ойлгов уу?

38-Р БҮЛЭГ

Хүн төрөлхтний төрөлхийн зан араншин буюу хүн төрөлхтний жинхэнэ нүүр царайг харгалзан үзвэл өнөөг хүртэл үргэлжлүүлж чаддаг байх нь үнэхээр амархан байгаагүй ба үүгээр л дамжуулан Бурханы агуу хүч чадал үнэхээр илэрхий болсон. Махан биеийн мөн чанар, мөн түүнчлэн одоог хүртэл агуу улаан луу хүнийг завхруулсан баримтыг бодоод үзвэл, Бурханы Сүнсний удирдамж байгаагүй бол хүн яаж өнөөдрийг хүртэл зогссоор байж чадах юм бэ? Хүн Бурханы өмнө очих эрхгүй боловч Бурхан Өөрийн удирдлагын төлөө, Өөрийн агуу ажлыг төд удалгүй хэрэгжүүлэхийн төлөө хүн төрөлхтнийг хайрладаг. Үнэнийг хэлэхэд хүн төрөлхтнийг гэх Бурханы хайрыг ямар ч хүн энэ насандаа хариулж огт чадахгүй. Магадгүй зарим хүн амиа золиослон Бурханы нигүүлслийг хариулахыг хүсдэг байх, гэхдээ Би чамд хэлье: Хүн Бурханы өмнө үхэх үнэ цэнгүй тул хүний үхэл хий дэмий байх болно. Яагаад гэвэл, Бурханы хувьд хүний үхэл бол бүр дурдахын ч хэрэггүй, сохор зоосны ч үнэгүй, газар дээрх шоргоолжны үхэлтэй адил. Би хүмүүст, өөрсдийгөө хэтэрхий өндрөөр үнэлэхгүй байж, Бурханы төлөө үхэх нь Тай уулын чинээ асар их хүндтэй гэж бодохгүй байхыг зөвлөе. Үнэндээ хүний үхэл бол ердөө өд мэт хөнгөн, дурдахын ч хэрэггүй юм. Гэвч нөгөө талаар хүний махан бие угаасаа үхэх үйлтэй тул махан бие эцэстээ газар дээр төгсгөл болох ёстой. Энэ бол хэн ч үгүйсгэж чадахгүй үнэн баримт юм. Энэ бол хүний амьдралын бүхий л туршлагаас Миний нэгтгэн дүгнэсэн “байгалийн хууль” тул нэг л мэдэхэд Бурхан хүний төгсгөлийг ийм маягаар тодорхойлсон. Чи ойлгов уу? Бурхан: “Би хүн төрөлхтний

дуулгаваргүй байдлыг жигшдэг. Яагаад гэдгийг нь мэдэхгүй; Би анхнаасаа хүнийг үзэн ядсан мэт санагддаг боловч тэднийг ихэд өрөвддөг. Тиймээс хүмүүс Надад үргэлж хоёр янзаар хандаж ирсэн—учир нь Би хүнийг хайрладаг, бас үзэн яддаг" гэж хэлсэнд гайхах юмгүй.

Байгаагийнх нь төлөө, эсвэл илрэлтийнх нь төлөө Бурханыг магтдаггүй хэн байна вэ? Энэ удаа Би хүний доторх бохир заваан, зөв шударга бус байдлыг бүрмөсөн мартчихсан мэт байдаг. Хүн төрөлхтний өөрийгөө зөвтгөдөг, өөрийгөө чухалчилдаг зан, дуулгаваргүй байдал, эсэргүүцэл, бүх тэрслүү байдлыг Би сэтгэлийнхээ мухарт хийгээд мартдаг. Хүн төрөлхтний эдгээр байдлаас болж Бурхан хязгаарлагддаггүй. Би Бурхантай адил "зовж шаналдаг" тул цаашид хүний хязгаарлалтад өртөх вий гэсэндээ Өөрийгөө энэ асуудлаас салгадаг. Тэгж төвөг удаж яах юм бэ? Хүн Надтай хамт Бурханы гэр бүлд нэгдэх хүсэлгүй байхад тэднийг хүчлэхийн тулд Би яаж Өөрийн хүч чадлыг ашиглаж чадах юм бэ? Би хүнийг дарангуйлах зүйлсийг хийдэггүй бөгөөд Би Бурханы гэр бүлд төрсөн учраас мэдээж хүн бид хоёр үргэлж өөр байдагт гайхах юмгүй. Энэ нь өнөөдрийн өрөвдөлтэй ялагдлын байдалд хүнийг хүргэсэн юм. Гэхдээ Би хүний сул талуудаас үргэлжлүүлэн зай барьдаг; Надад ямар сонголт байгаа юм бэ? Би хүчин мөхөс болохоор тэр бус уу? Бурхан хүн төрөлхтний "ажлын хэсгээс" "тэтгэвэрт гарахыг" хичээж, түүнчлэн "тэтгэвэр" нэхдэгт гайхах юм алга. Намайг хүний өнцгөөс ярих үед хүн сонсдоггүй, гэхдээ Бурханы өнцгөөс ярих үед минь ч гэсэн хүн дуулгаваргүй байхаа ер нь больсон бил үү? Магадгүй Бурхан гэнэт хүн төрөлхтний "ажлын хэсгээс" "тэтгэвэрт гарах" өдөр ирэх байх, тэр цаг ирэхэд Бурханы үг бүр ч илүү ширүүн болно. Өнөөдөр Надаас болоод Бурхан ийм маягаар ярьдаг байж магадгүй бөгөөд хэрвээ тэр өдөр ирвэл Бурхан Надтай адил эелдэг зөөлнөөр, тэвчээртэйгээр "цэцэрлэгийн хүүхдүүдэд үлгэр ярихгүй". Магадгүй Миний хэлж байгаа зүйл төдийлөн тохиромжгүй ч бие махбодтой болсон Бурханы төлөө л Бурхан хүнийг барих барьцаа бага зэрэг сулруулахад бэлэн байдаг; эс бөгөөс, хэтийн төлөвийг эргэцүүлэн бодоход дэндүү аймшигтай байх болно. Бурханы хэлсэнчлэн, "Би нэгэнтээ хүмүүсийг барих барьцаа тодорхой хэмжээнд сулруулж, махан биеийнхээ хүсэлд дурааараа ташуурах боломж олгосон—үүнээс болоод тэд эрээ цээргүй цадиггүй авирлаж зүрхэлсэн ба бүгд махан биед амьдарч байгаа учраас Намайг үнэхээр хайрладаггүй гэдгийг үүнээс харж болно." Бурхан энд яагаад "хүсэлдээ ташуурах" болон "махан биед амьдарч байгаа" гэж хэлсэн бэ? Үнэнийг хэлэхэд хүн Миний тайлбаргүйгээр ийм үгийг аяндаа ойлгоно. Зарим хүн ойлгохгүй байна гэж хэлж магадгүй бөгөөд энэ бол, хариултыг нь хэдийнээ мэдэж байгаа мөртөө мэддэггүй дүр эсгэж байгаа хэрэг гэж Би хэлнэ. Цөөн хэдэн үгийг сануулъя: Яагаад Бурхан "Би хүнээс Надтай хамтран ажиллахыг л шаарддаг" гэж хэлдэг вэ? Бас Бурхан яагаад хүний уг чанарыг өөрчлөхөд хэцүү гэж хэлдэг вэ? Бурхан яагаад хүний уг чанарыг жигшдэг вэ? Хүний уг чанар яг юу юм бэ? Хүний уг чанарын гаднах зүйл юу юм бэ? Эдгээр асуултыг тунгаан бодсон хүн байна уу?

Магадгүй энэ нь хүний хувьд шинэ сэдэв байж болох ч үүнийг зохих ёсоор анхааран үзэхийг Би хүнээс гуйсаар байдаг, эс бөгөөс “хүний уг чанарыг өөрчлөхөд хэцүү” гэх мэт үгээс болоод хүн үргэлж Бурханыг гомдооно. Тийм маягаар Түүнтэй сөргөлдөх ямар хэрэгтэй юм бэ? Эцсийн эцэст зүгээр л гай дуудаж байгаа бус уу? Энэ нь чулуу руу өндөг шидэж байгаатай адил төгсгөлд хүргэх бус уу?

Үнэндээ хүнд тулгардаг бүх шалгалт, сорилт нь хүнийг сур гэж Бурханы шаарддаг хичээлүүд юм. Бурханы санаа зорилгын дагуу бол, хүн хайрладаг зүйлээ золиослох ёстой болсон ч гэсэн эдгээр зүйлийг биелүүлж чадна, гэхдээ хүн үргэлж өөрийгөө хайрладаг учраас Бурхантай үнэхээр хамтран ажиллаж чаддаггүй. Бурхан хүнээс их юм шаарддаггүй. Хүнээс Бурханы шаарддаг бүхэн амархнаар, аз жаргалтайгаар биелэх учиртай; хүн л зовлон бэрхшээл туулахыг хүсдэггүй. Яг л хүүхэд нь эцэг эхээ асарч халамжлахын тулд мөнгөө хэмнэж, хуримтлуулан амьдарснаар үүргээ биелүүлж чаддагтай адилхан. Гэсэн ч тэд хангалттай сайн хооллохгүй байхаас, хувцас нь хэтэрхий энгийн байхаас айдаг тул янз бүрийн шалтгаанаар эцэг эхийнхээ хайр халамжийн ачийг хариулахаа бүрмөсөн умартаад, тэднийг халамжлах ажил баяжих хүртэл нь хүлээж болох мэт байдаг. Хүмүүст эцэг эхээ хайрлах ачлал элбэрэл байдаггүй гэдгийг Би үүнээс хардаг—тэд бүгд ачлалгүй хүүхдүүд. Миний уг хэтэрхий туйлширсан байж болох ч Би бодит баримтуудын өмнө учир утгагүй юм ярьж чадахгүй. Би Өөрийгөө сэтгэл хангалуун байлгахын төлөө Бурханыг эсэргүүцэхдээ “бусдыг дуурайж” чадахгүй. Газар дээрх хэн ч ачлалтай сэтгэлтэй биш учраас л Бурхан ийнхүү хэлсэн: “Тэнгэрт Сатан Миний дайсан; газар дээр хүн Миний өстөн. Тэнгэр, газрын хоорондох нэгдлээс үүдэн Би тэднийг ес дэх үеэ хүртэл бүгд буруутай гэж үздэг.” Сатан бол Бурханы дайсан; Бурхан ингэж хэлдгийн шалтгаан нь, тэр Бурханы агуу ивээл, сайхан сэтгэлийн ачийг хариулдаггүй, харин ч “усны урсгалын эсрэг сэлдэг” ба ингэснээр Бурханд ачлал элбэрлээ харуулах үүргээ биелүүлдэггүй. Хүмүүс ч бас ийм байдаг бус уу? Тэд “эцэг эхдээ” ямар ч ачлал хүндлэл үзүүлдэггүй ба “эцэг эхийнхээ” хайр халамжийн ачийг хэзээ ч хариулдаггүй. Газар дээрх хүмүүс бол тэнгэр дэх Сатаны хамаатан садан юм гэдгийг харуулахад энэ хангалттай. Хүн, Сатан хоёр нэгэн зүрх сэтгэл, оюун ухаанаар Бурханыг эсэргүүцдэг тул Бурхан есөн үеэр нь татан оролцуулаад, хэнийг ч өршөөхгүй байхад гайхах юмгүй. Урьд нь Бурхан тэнгэр дэх хүлцэнгүй зарцаараа хүн төрөлхтнийг удирдуулсан боловч тэр дуулгавартай байгаагүй, харин өөрийн зан араншинг өөгшүүлж, тэрсэлсэн юм. Тэрслүү хүмүүс ч бас энэ замаар алхаж байгаа бус уу? Бурхан “жолоо цулбууруа” хэчнээн их чангалсан ч хамаагүй хүмүүс ердөө ганхахгүй ба замаасаа буцаж чадахгүй. Миний үзэл бодлоор хэрвээ хүмүүс ийм маягаар үргэлжлүүлбэл өөрсдийгөө сүйрүүлнэ. Магадгүй одоо чи “Хүмүүс хуучин уг чанарынхаа ужиг хүлээсийг тастах чадваргүй” гэсэн Бурханы үгийн жинхэнэ утгыг ойлгоно. Бурхан хүнд хэд хэдэн удаа сануулсан: “Хүний дуулгаваргүй байдлаас болоод Би түүнийг орхидог.” Бурхан яагаад үүнийг ахин дахин хэлдэг вэ? Бурхан үнэхээр тийм цэвдэг юм гэж үү? Яагаад Бурхан бас

“Би бол хүн төрөлхтний нэг биш” гэж хэлдэг юм бэ? Маш их цаг завтай өдрүүддээ эдгээр нарийн асуудлыг хэн үнэхээр анхааралтай бодож үзсэн бэ? Бурханы үгэнд илүү их хичээл чармайлт зарцуулж, тэдгээрт хааш яаш хандахгүй бай гэж Би хүн төрөлхтнийг шавдуулдаг; ингэх нь чамд ч, эсвэл бусад хүнд ч ямар ч ашиггүй. Хэлэх хэрэггүй зүйлийг хэлэхгүй байж, тунгаан бодох хэрэггүй зүйлийн талаар бодохгүй байх нь дээр. Энэ нь илүү энгийн байх бус уу? Ингэж хэрэгжүүлэхэд юу нь буруу байх билээ? Бурхан газар дээрх ажлынхаа төгсгөлийг тунхаглахаас өмнө хэн ч “хөдлөхөө” больж болохгүй; хэн ч үүргээсээ булталж болохгүй. Одоо цаг нь биш; Бурханы хөтөч юм уу манлайлагч мэт бүү авирла. Одоо зогсоод, урагш явахаа болиход хэтэрхий эртэднэ гэж Би бодож байна—чи юу гэж бодож байна вэ?

Бурхан хүмүүсийг гэсгээлтэн дунд аваачиж, үхлийн уур амьсгал руу аваачсан ч эсрэгээрээ Бурхан газар дээрх хүнээр юу хийлгэх вэ? Мэдээж, идэж, өмсөж болохгүй, харин харж л болдог Бурханы гэр дэх хувцасны шүүгээ болох нь хүний зорилго биш. Хэрвээ тийм л байх байсан бол хүмүүсийн махан биеийг тэгэж их зовоохын тулд ийм олон төвөгтэй үйл явцыг ашиглах юунд хэрэгтэй гэж? Бурхан: “Хүний гэмт хэрэг Миний гэсгээлтийг хүртэхэд хангалттай болохоор Би хүнийг ‘цаазын тавцан’ руу дагалдан явдаг” гэсэн. Энэ удаа Бурхан хүмүүсийг өөрсдийг нь цаазын тавцан руу алхуулдаг уу? Яагаад хэн ч “тэдний төлөө өршөөл эрдэггүй” юм бэ? Тэгвэл хүн яаж хамтран ажиллах ёстой вэ? Бурхан шүүлтээ хийдгийн адилаар хүн үнэхээр сэтгэл хөдлөлийн нөлөөнд автахгүйгээр үйлдэж чадах уу? Эдгээр үгийн үр нөлөө үндсэндээ хүн хэрхэн үйлдэхээс хамаардаг. Эцэг нь мөнгө олоод гэртээ авч ирэхэд ээж нь эцэгтэй нь хэрхэн хамтран ажиллахаа мэдэхгүй, өрхийн ахуйгаа хэрхэн удирдахаа мэдэхгүй бол тэр айл ямар байдалд орох вэ? Чуулганы одоогийн байр байдлыг хар: Удирдагчдын хувиар та нарт ямар санагдаж байна вэ? Та нар хувийн сэтгэгдлээ ярилцах уулзалт хийж болох юм. Ээж нь гэр дэх зүйлсээ сүйдэлдэг бол тийм гэр бүлийн хүүхдүүд ямар харагдах вэ? Өнчин хүүхдүүд шиг үү? Гуйлгачид шиг үү? Бурхан: “Хүмүүс бүгд Намайг ‘оюуны чадавх’ дутмаг бурханлаг чанартай гэж боддог боловч хүн чанараараа бүх зүйлийг нэвт шувт харж чадна гэдгийг минь хэн ухаарч чадах билээ?” гэж хэлсэнд гайхах юмгүй. Тийм илэрхий нөхцөл байдлын тухайд бол Бурхан Өөрийн бурханлаг чанарын үүднээс ярих хэрэггүй. Бурханы хэлсэнчлэн “Хадаас хадахад лантуу ашиглах хэрэггүй.” Энэ удаа, “Хүмүүсийн дунд Намайг хайрладаг хэн ч үгүй” хэмээх Бурханы онч үгийг бодитоор туулсан хүмүүс байгаа байх. Энэ мөчид яг л Бурханы хэлсэнчлэн: “Өнөөгийн нөхцөл байдлаас болоод хүмүүс бүгд дурамжхан толгой бөхийдөг боловч зүрх сэтгэлдээ үнэмшээгүй хэвээр үлддэг.” Эдгээр үг дуран мэт байдаг. Ойрын ирээдүйд хүн өөр нөхцөл байдалд алхан орсон байна. Үүнийг засаршгүй байдал гэж нэрлэдэг. Ойлгож байна уу? Тэр нь Бурханы энэ хоёр асуултын хариу юм: “Хүмүүс Намайг явна гэж айсандаа л нүглээс татгалздаг бус уу? Тэд гэсгээлтээс айсандаа л гомдоллодоггүй гэдэг нь үнэн бус уу?” Үнэндээ одоогийн үе шатанд хүмүүс бага зэрэг үлбэгэр, ядарч туйлдсан мэт байдаг. Тэд Бурханы ажлыг

анхаарах талаар огт боддоггүй ба гагцхүү махан биеийнхээ төлөө зохицуулалт, төлөвлөгөө гаргахад л анхаардаг. Тийм биз дээ?

39-Р БҮЛЭГ

Бурханы үгээс даван гараад, амиа улам цэцэглүүлж, биднийг гэх Бурханы найдварыг биелүүлэхийн тулд өөрсдийнхөө амьтай холбоотой хэрэг явдлуудын талаар бага зэрэг ярилцацгаая. Ялангуяа, бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах цаг үе, гэсгээлтийн цаг үе болох өнөөдөр хүрэлцэн ирсэн болохоор ерөнхий нөхцөл байдлыг анхаарч, “хамтын ашиг сонирхол” дээр анхаарлаа төвлөрүүлэх нь илүү чухал. Энэ нь Бурханы хүсэл бөгөөд бүх хүний биелүүлэх ёстой зүйл юм. Бид тэнгэр дэх Бурханы хүслийн төлөө өөрсдийгөө өргөн барихгүй байж яаж чадах билээ? Бурхан “бүх төрлийн хүмүүсийг дугаарлаж, төрөл бүрийн хүнийг өөр өөр тэмдгээр тэмдэглэдэг, ингэснээр өвөг дээдэс нь тэднийг гэр бүл рүүгээ буцаан аваачиж чадах” ба хүмүүс төрлийнхөө дагуу ангилагдаж, үүний үр дүнд бүх төрлийн хүмүүс жинхэнэ төрхөө үзүүлж байгааг энэ нь харуулдаг. Тийм болохоор хүмүүс Бурханд биш, харин өвөг дээдэстээ үнэнч гэж хэлэх нь зүйтэй. Гэхдээ бас бүх хүн өвөг дээдсийнхээ зааварчилгааны дор Бурханд үйлчлэл үзүүлж байгаа нь Бурханы ажлын гайхалтай байдал юм. Бүх зүйл Бурханд үйлчилж байгаа бөгөөд Сатан хүмүүсийг үймүүлдэг хэдий боловч Бурхан энэ боломжийг ашиглан Өөрт нь үйлчлэх “дотоод нөөцийг” татдаг. Хүмүүс гэхдээ үүнийг ялган салгаж чаддаггүй. Бурханы хэлснээр, “Тиймээс Би бас хөдөлмөрөө хувааж, хичээл чармайлтаа хуваарилдаг. Энэ бол Миний төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд нэг ч хүн үүнийг тасалдуулж чадахгүй.” Хүмүүс Бурханы тогтоосон бүхнийг, Бурханы биелүүлэхийг хүссэн бүхнийг Бурханыг хийхээс нь өмнө харж чаддаггүй. Бурханы ажил дууссан үед л тэд үүнийг харж чадна; эс бөгөөс тэд сохор бөгөөд юу ч хардаггүй.

Өнөөдөр, чуулганууудын дундах шинэ ажил Бурханд бий. Тэрээр бүх зүйлийг байгалийн жамаар нь явуулж, хүний чиг үүргийг үнэхээр биелүүлнэ. Бурханы хэлсэнчлэн “Би бүх зүйлийн дунд буй бүхнийг захирч, бүх зүйлийн дундах бүх юмыг удирдаж, бүх зүйлийг байгалийн жамаар нь явуулж, байгалийн хуулинд захирагдуулдаг.” “Байгалийн жамаар нь явуулах” гэдгийн талаар ямар ухаалаг ойлголт та нарт байгааг Би мэдэхгүй болохоор энэ талаар ярилцья. Би үүнийг ингэж үздэг: Тэд өвөг дээдсээрээ замчлуулан харьж байгаа учраас төрөл бүрийн хүмүүс гарч ирж, “ажиллах” ёстой. Тэд байгалийн жамыг дагаж байгаа учраас тэдэнд төрөлхөөсөө байдаг зүйл нь анхдагч чиг үүргээ биелүүлэхэд нь хэрэглэгдэж, энэхүү жамын дагуу Ариун Сүнсний удирдамжийг дагахад тэднийг хүргэдэг. Ариун Сүнсний ажил хүн бүрийн доторх байр байдлын дагуу хийгддэг; нарийн яривал үүнийг “Өөрийнхөө төлөө ажиллуулахын тулд Бурхан бүх зүйлийг залах” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь байгалийн жамыг дагахтай холбоотой байдаг. Хэдийгээр хүний дотор

диаволын элементүүд байдаг боловч Бурхан үүнийг ашиглаж, тэдний дотор төрөлхөөсөө байдаг зүйлийн суурин дээр Ариун Сүнсний ажлыг нэмээд, Бурханд үйлчлэл үзүүлэхэд хангалттай болгодог. “Байгалийн жамаар нь явуулах” тухай Миний хэлэх бүхэн энэ—магадгүй та нарт илүү дээр санал байгаа байх. Та нарыг зарим нэг үнэтэй санал хэлнэ гэж Би найдаж байна. Тэгвэл ямар вэ? Та нар байгалийн жамыг дагахад хамтран ажиллахад бэлэн үү? Бурхантай хамт ажлыг хуваалцахад бэлэн үү? Үүнийг яаж биелүүлэх талаар ер нь бодож үзсэн үү? Хүмүүс Бурханы хүслийг ойлгож, хамтын туйлын зорилгын төлөө Бурханыг хангалуун байлгахаар санаа нэгдэж, хаанчлалын замаар хамтдаа урагшилж чадна гэж Би найдаж байна. Шаардлагагүй үзлүүдийг бодож олох ямар хэрэгтэй юм бэ? Өнөөдрийг хүртэл хэний оршин тогтнол Бурханы төлөө байгаагүй вэ? Нэгэнт ийм болохоор уй гашуу, уйтгар гуниг, санаа алдалт ямар хэрэгтэй юм бэ? Энэ нь хэнд ч ямар ч ашиггүй. Хүмүүсийн бүхий л амьдрал Бурханы гарт байдаг бөгөөд Бурханы өмнөх шийдвэр нь байгаагүй бол хүний энэ хоосон ертөнцөд хий дэмий амьдрахыг хэн хүсэх юм бэ? Ямар хэрэгтэй юм бэ? Дэлхийд яаран ирж, буцахдаа хэрвээ тэд Бурханы төлөө юу ч хийгээгүй бол бүхий л амьдрал нь талаар өнгөрөх бус уу? Бурхан чиний үйлдлийг дурдахад зохистой гэж үзэхгүй байсан ч гэсэн чи насан эцэслэх мөчдөө сэтгэл ханамжтай инээмсэглэл тодруулах бус уу? Чи сөрөг ухралтыг биш, харин эерэг ахиц дэвшлийг эрэлхийлэх ёстой—энэ нь илүү дээр хэрэгжүүлэлт биш гэж үү? Хэрвээ чиний үйлдэл гагцхүү Бурханыг хангалуун байлгахын төлөө байдаг бол чи сөрөг байх юм уу ухарч няцахгүй. Хүмүүсийн зүрх сэтгэлд ойлгогдошгүй зүйлс үргэлж байдаг учраас өөрийн мэдэлгүй тэдний царай бүрхэг тэнгэр мэт барайдаг ба нэг л мэдэхэд тэдний царайд хэд хэдэн “гүн үрчлээс” үүсгэж, газар хагарснаас бий болсон мэт санагдуулдаг. Газар нүүдэллэн хөдөлж, газар дээрх “толгод” юм уу “хонхрууд” хүмүүст мэдэгдэлгүйгээр байраа сэлгэж байгаа мэт байдаг. Үүгээрээ Би хүмүүсийг дооглож байгаа юм биш, харин “газар зүйн мэдлэгийн” талаар ярьж байна.

Хэдийгээр Бурхан бүх хүнийг гэсгээлт рүү хөтөлсөн боловч Тэр энэ талаар юу ч хэлдэггүй. Харин ч Тэрээр зориуд энэ сэдвээс зайлсхийж, шинэ сэдэв эхлүүлдэг, энэ нь нэг талаар Бурханы ажлаас болж байгаа, нөгөө талаар ажлын энэ алхмыг даруйхан дуусгахын төлөө байдаг. Ажлын энэ алхмыг гүйцэтгэх Бурханы зорилго аль хэдийн биелсэн учраас цаашид ярих хэрэггүй. Өнөөдөр та нар Бурханы ажлын арга барилаас хэр ихийг харсаныг Би мэдэхгүй; Бурханы ажил урьдынх шигээ үе шат, цаг хугацаанд тодорхой хуваагддаггүй гэдгийг Би ухамсартаа үргэлж мэдэрдэг. Харин, өдөр бүр өөрийн гэсэн ажиллах арга барилыг авчирч, бараг гурваас таван өдөр тутамд өөрчлөлт гардаг ба тав хоногийн дотор ч Бурханы ажилд хоёр өөр төрлийн агуулга байж болно. Энэ нь Бурханы ажлын хурдыг харуулдаг; хүмүүс хариу үйлдэл хийж, ойроос харж чадахаас өмнө Бурхан ул мөргүй алга болдог. Тиймээс Бурхан үргэлж хүмүүсийн хувьд хүршгүй байдаг ба энэ нь Ариун Сүнсний ажлын үл ажиглагдам байхад хүргэсэн. Бурхан “иймээс Би

хүнийг орхисон” гэх мэт үгийг яагаад үргэлж хэлдэг юм бэ? Хүмүүс эдгээр үгэнд багахан анхаарал хандуулж магад боловч утга учрыг нь ойлгодоггүй. Одоо яаж байна вэ, та нар ойлгож байна уу? Хүмүүс Ариун Сүнсний байгааг ухаардаггүйд гайхах юмгүй. Бурханыг гэсэн тэдний эрэл хайгуул үргэлж бүүдгэр сарны гэрэл дор байдаг—энэ нь яг үнэн бөгөөд Бурхан санаатайгаар хүнээр тохуурхаж, бүх хүний ууриг тархийг хавагнуулдаг болохоор тэдний толгой эргэж, замаа алдсан мэт байдаг. Тэд юу хийж байгаагаа дөнгөн данган мэддэг; тэд зүүдэлж байгаа мэт байдаг ба сэрмэгцээ юу тохиолдсоныг мэддэггүй. Бурханы зарим нэг энгийн үг л хүмүүсийг яахаа мэдэхгүй болгож орхидог. Тиймээс Бурхан “Өнөөдөр Би бүх хүнийг цэвэршүүлэхийн тулд ‘асар том зуух’ руу шиддэг. Би өндөрт зогсоод хүмүүс галд шатаж, галын дөлөнд хуйхлуулж байгааг анхааралтай харж байдаг ба хүмүүс галын шахалтад автаад баримтуудыг өчдөг” гэж хэлсэнд гайхах юмгүй. Бурханы байнга өөрчлөгдөж байдаг үгийн дунд хүмүүс юу хийхээ огт мэддэггүй; үнэндээ Бурханы хэлснээр гэсгээлт аль хэдийн эхэлчихсэн бөгөөд хүмүүс үүнийг ухааraагүй учраас Бурханыг маш тодорхой хэлэхэд л үүнийг мэддэг, Бурханыг өөрсдөд нь хэлсний дараа л тэд анхаарлаа хандуулдаг. Бурханы ажил өдий хүртэл хийгдсэн болохоор л хүмүүс одоо гэсгээлтийг судалж эхэлж байгаа гэж хэлж болно. Хүмүүс цөмийн бөмбөгний талаар мэддэг болсон үетэй энэ нь яг адилхан—гэхдээ цаг нь болоогүй учраас хүмүүс анхаарал хандуулдаггүй; хэн нэгэн үүнийг бүтээж эхлэхэд л хүмүүс анхаарал тавьж эхэлдэг. Цөмийн бөмбөг ил болох үед л хүмүүс энэ талаар илүү ойлгодог. Бурхан хүмүүсийг зуух руу шиднэ гэж хэлэх үед л хүмүүс бага зэрэг мэддэг болсон. Хэрвээ Бурхан хэлээгүй бол хэн ч мэдэхгүй байх байсан—тийм биш гэж үү? Иймээс Бурхан “Хүмүүс олсоор хөтлүүлж яваа юм шиг, мөн мэдрэлгүй болсон юм шиг өөрийн мэдэлгүй зууханд ордог” гэж хэлдэг. Үүнийг шинжлэн үзвэл ямар вэ: Хүмүүс баримтуудыг өчих үе нь гэсгээлт эхэлсэн гэж Бурханы хэлсэн үе үү, эсвэл гэсгээлт эхэлсэн гэж Бурханыг хэлэхээс өмнөх үе үү? Эндээс харахад, Бурханыг гэсгээлтийн талаар ярихаас өмнө хүмүүс буруугаа хүлээж эхэлсэн ба Бурханыг энэ талаар ярихаас өмнө гэсгээлт эхэлснийг энэ нь харуулдаг—энэ нь баримт биш гэж үү?

40-Р БҮЛЭГ

Бурханы хувьд хүн Түүний атган дахь тоглоомтой адилхан, мөн Түүний гарт байгаа сунгасан гоймон буюу таалалд нь нийцэхийн тулд Бурханы хүссэнээр нимгэн юм уу зузаан болдог гоймонтой адилхан. Хүн үнэхээр нэгэн хатагтайн зах дээрээс худалдаж авсан Перс мууртай адил, Бурханы гар дахь тоглоом юм гэж хэлэхэд болно. Тэр бол Бурханы гар дахь тоглоом гэдэг нь эргэлзээгүй—иймээс Петрийн мэдлэгт ямар ч буруу юм байгаагүй. Хүн дээрх Бурханы үг болон үйлдэл амархан, тааламжтайгаар биелдэг гэдгийг үүнээс харж болно. Тэр хүмүүсийн

төсөөлдөг шиг тархиа гашилгах юм уу төлөвлөгөө зохиодоггүй; хүнд Түүний хийдэг ажил тун хэвийн байдаг, хүнд айлддаг Түүний үг ч мөн адил. Ярих үедээ Бурхан хэтэрхий их чалчиж байгаа юм шиг санагддаг ба Тэр ямар ч хаязгаарлалтгүйгээр санаанд нь орсон бүхнийг хэлдэг. Гэхдээ Бурханы үгийг уншсаны дараа хүмүүс бүрэн үнэмшиж, нүдээ бүлтийлгэн, цочирдон гайхаад, хэлэх ч үггүй болдог. Энд юу болоод байна вэ? Энэ нь Бурханы мэргэн ухаан хэчнээн их болохыг сайтар харуулдаг. Хэрвээ хүмүүсийн төсөөлдөг шигээр, хүн дээрх Бурханы ажил яг таг, үнэн зөв байхын тулд нягт нямбай төлөвлөгдөх ёстой байсан бол—эдгээр төсөөллийг нэг алхам ахиулахын тулд—Бурханы мэргэн ухаан, гайхалтай, ойлгогдошгүй байдлыг тоогоор тодорхойлдог байх байсан ба Бурханыг үнэлэх хүмүүсийн үнэлгээ хэтэрхий доогуур гэдгийг энэ нь харуулдаг. Хүмүүсийн үйлдэлд тэнэглэл үргэлж байдаг болохоор тэд Бурханыг мөн адилаар хэмждэг. Бурхан Өөрийнхөө ажлын төлөө төлөвлөгөө гаргадаггүй, эсвэл зохицуулалт хийдэггүй; харин үүнийг Бурханы Сүнс шууд гүйцэтгэдэг—Бурханы Сүнсний ажилладаг зарчмууд нь чөлөөтэй агаад хязгаарлалтгүй байдаг. Бурхан хүний байр байдалд анхаарал хандуулалгүй хүссэнээрээ ярьдаг мэт байдаг—гэсэн ч хүн өөрийгөө Бурханы үгээс салгаж бараг чаддаггүй нь Бурханы мэргэн ухаанаас болж байгаа юм. Эцсийн эцэст баримтууд бол баримтууд. Бүх хүн дэх Бурханы Сүнсний ажил маш илэрхий байдаг учраас энэ нь Бурханы ажлын зарчмуудыг хангалттай харуулдаг. Хэрвээ Бурхан, бүтээгдсэн зүйлст хийх ажилдаа тийм их төлөөс төлөх хэрэгтэй байсан бол тэр нь сайхан банзыг ялихгүй юманд хэрэглэж байгаа хэрэг биш гэж үү? Бурхан биечлэн хийх ёстой гэж үү? Ингэх нь зохистой гэж үү? Бурханы Сүнс маш удаан хугацаанд ажилласаар ирсэн ч эрин үеүдийн туршид Бурханы Сүнс хэзээ ч ийм маягаар ажиллаж байгаагүй учраас Бурханы ажилладаг арга барил болон зарчмуудыг хэн ч, хэзээ ч мэдээгүй, тэд хэзээ ч тодорхой ойлгоогүй. Өнөөдөр тэд тодорхой ойлгосон, учир нь Бурханы Сүнс тэдгээрийг биечлэн илчилсэн—энэ нь маргаангүй бөгөөд үүнийг хүн нэгтгэн дүгнээгүй, харин Бурханы Сүнс шууд харуулсан билээ. Гурав дахь тэнгэр рүү аялаад, үнэхээр ийм зүйл тохиолдож байгаа эсэхийг харж, мөн энэ бүх ажлыг хийсний дараа Бурханы ажил хөдөлмөр Түүнийг ядрааж, нурууг нь өвтгөж, хөлийг нь янгинуулж, эсвэл идэж, унтаж чадахааргүй болгож орхисон эсэхийг харж; Бурхан энэ бүх үгийг хэлэхийн тулд асар олон лавлах материал унших хэрэгтэй болж, Бурханы айлдваруудын ноорог ширээн дээгүүр нь хөглөрч, маш их ярьсныхаа дараа Түүний ам хатаж байсан эсэхийг харж яагаад болохгүй гэж. Баримтууд яг эсрэгээр байдаг: Дээрх үгэнд Бурханы оршин суудаг газартай адил төстэй зүйл огт үгүй. Бурхан: “Би хүний төлөө маш их цаг зарцуулж, асар их төлөөс төлсөн—гэхдээ энэ удаа үл мэдэгдэх учир шалтгааны улмаас хүмүүсийн мөс чанар анхдагч чиг үүргээ биелүүлж огт чадахгүй хэвээр үлддэг” гэсэн. Хүмүүс Бурханы уй гашууг мэдэрдэг эсэх нь хамаагүй, хэрвээ мөс чанараасаа зөрөлгүйгээр Бурханы хайранд хандаж чадвал энэ нь ухаалаг агаад боломжийн гэж тооцогдоно. Тэд мөс чанарынхаа анхдагч чиг

үүргийг биелүүлэхийг хүсэхгүй гэдгээс л айж байна. Энэ нь зөв үү, чи юу гэх вэ? Эдгээр үг чамд тусалдаг уу? Та нар мөс чанаргүй хог хаягдал байхын оронд мөс чанартай зүйлд харьяалагддаг гэж Би найдаж байна. Энэ үгийн талаар та нар юу гэж бодож байна вэ? Үүнийг мэдэрч байгаа хүн байна уу? Зүрх рүү чинь зүүгээр хатгахад өвдөхгүй байна уу? Бурхан мэдрэмжгүй цогцост зүү хатгадаг уу? Бурхан андуурдаг уу, өндөр нас нь Түүний хараг муутгасан уу? Ийм байх боломжгүй гэдгийг Би хэлье! Ямартай ч энэ нь хүний алдаа байх учиртай. Эмнэлэгт очоод, шалгуулж яагаад болохгүй гэж? Хүний зүрхэнд асуудал байгаа нь гарцаагүй; үүнийг шинэ “сэлбэг” хийх хэрэгтэй—юу гэж бодож байна? Та нар тэгэх байсан уу?

Бурхан: “Би хүний муухай царай болон хачин байдлыг хардаг бөгөөд дахин нэгэнтээ хүнийг орхин явдаг. Ийм нөхцөл байдалд хүмүүс ойлгохгүй хэвээр үлддэг бөгөөд Миний татгалзсан зүйлсийг дахин нэгэнтээ буцаан авч, эргэн ирэхийг минь хүлээж байдаг” гэж хэлсэн. Энэхүү “шинэ технологийн эрин үед” Бурхан яагаад үхэр тэрэгний талаар ярьсаар байна вэ? Яагаад тэр вэ? Бурхан үглэх дуртай учраас уу? Түүнд өөр хийх юм байхгүй учраас Бурхан цаг нөхцөөж байгаа юу? Цадталаа идсэнийхээ дараа цагийг дэмий үрж буй хүнтэй Бурхан адилхан гэж үү? Эдгээр үгийг дахин ахин давтах нь хэрэгтэй юу? Хүмүүс бол өөдгүй амьтад бөгөөд тэдэнд сонсгохын тулд чихнээс нь үргэлж зулгаах ёстой гэж Би хэлсэн. Өнөөдөр тэдэнд үг хэлсний дараа маргааш тэд дорхноо мартана—тэд ой тогтоолт муудах өвчнөөр өвдсөн мэт байдаг. Тиймээс зарим үгийг хэлээгүй юм биш, харин хүмүүс хэрэгжүүлээгүй юм. Хэрвээ ямар нэгэн зүйлийг ганц хоёр удаа хэлээд хүмүүс мэдэхгүй хэвээр байвал—үүнийг гурван удаа хэлэх ёстой, энэ нь хамгийн бага хэмжээ юм. Тэр ч бүү хэл, зарим “хөгшин хүнд” арваас хорин удаа хэлэх хэрэгтэй байдаг. Ийм маягаар, хүмүүс өөрчлөгдсөн эсэхийг харахын тулд нэг зүйлийг ахин дахин өөр өөр аргаар хэлдэг. Та нар үнэхээр ийм маягаар ажилласан уу? Би хүмүүсийг занахыг хүсдэггүй боловч тэд бүгд Бурханаар тоглож байгаа; хүнсний нэмэлт бүтээгдэхүүн идэж уухаа тэд бүгдээрээ мэддэг боловч Бурханаас болж түгшдэггүй—энэ нь Бурханд үйлчилж байгаа хэрэг үү? Бурханыг хайрлаж байгаа хэрэг үү? Тэд энэ дэлхий дээр санаа зоволгүйгээр, хий дэмий, идэвхгүйгээр бүхий л өдрийг өнгөрүүлдэгт гайхах зүйлгүй. Гэхдээ тэгсэн ч гэсэн зарим хүн мөн л сэтгэл ханадаггүй бөгөөд өөрсдийнхөө уй гашууг бий болгодог. Би бага зэрэг хатуу байж магадгүй боловч энэ нь өөрийнхөө талаар хэтэрхий уян сэтгэлтэй байх гэж нэрлэгддэг зүйл юм! Бурхан чамайг уй гашуутай болгож байгаа гэж үү? Чи өөрөө өөртөө зовлон авчирч байгаа юм биш үү? Бурханы нигүүлслийн нэг нь ч чиний аз жаргалын эх сурвалж байхад тохирохгүй гэж үү? Чи цаг ямагт Бурханы хүслийг хайхраагүй бөгөөд сөрөг, эмгэг хуучтай, гутруу байсаар ирсэн—яагаад энэ вэ? Чамайг махан биед амьдруулах нь Бурханы хүсэл үү? Чи Бурханы хүслийг мэддэггүй, зүрх сэтгэлдээ тайван бус байж, үглэж, гомдоллодог бөгөөд бүхий л өдрийг уруу царайлж өнгөрүүлдэг, махан бие чинь шаналал, тарчлаан амсдаг—та нарын хүртэх ёстой зүйл бол энэ! Гэсгээлтийн дунд Бурханыг магтаж, гэсгээлтээс

гарч ирж, үүгээр хязгаарлагдахгүй байхыг та нар бусдаас хүсдэг ч өөрсдөө үүнд унасан бөгөөд зугтаж чаддаггүй. Дон Цунруй-гийнх шиг “өөрийгөө золиослох сэтгэлийг” дуурайхад олон жил шаардагддаг. Үг болон сургаалыг номлох үедээ чи ичдэггүй юу? Чи өөрийгөө мэдэх үү? Өөрийгөө хойш тавьсан уу? Чи Бурханыг үнэхээр хайрладаг уу? Хэтийн ирээдүй, хувь заяагаа хойш тавьсан уу? Хүмүүс гайхмаар агаад ойлгохын аргагүй гэж Бурхан хэлдэгт гайхах юмгүй. Хараахан ухан гаргаагүй маш олон “эрдэнэс” хүний дотор байсан гэж хэн бодох билээ? Өнөөдөр үүний харагдах байдал нь “хүний нүдийг нээхэд” хангалттай—хүмүүс үнэхээр “гайхалтай”! Би тоолж ч чадахгүй хүүхэд юм шиг л байдаг. Өнөөдөр ч гэсэн, хэчнээн олон хүн Бурханыг үнэхээр хайрладгийг Би олж мэдээгүй л байгаа. Би хэзээ ч тоог нь санаж чадахгүй—иймээс Миний “үнэнч бус байдлаас” болоод Бурханы өмнө тайлан өгөх цаг ирэхэд Би үргэлж гар хоосон, хүссэнээ хийх чадваргүй байдаг бөгөөд үргэлж Бурханд өртэй байдаг. Үүний үр дүнд, тайлан өгөхдөө Би үргэлж Бурханаар “зэмлүүлдэг.” Яагаад хүмүүс ийм харгис байж, үүнээс болоод Намайг үргэлж зовоож байдгийг Би мэдэхгүй. Хүмүүс энэ боломжийг ашиглаад элгээ хөштөл инээдэг, тэд үнэхээр Миний найзууд биш. Намайг төвөгтэй байдалд орох үед тэд Надад ямар ч тусламж үзүүлдэггүй, харин Намайг зориуд дооглодог—тэд үнэхээр ямар ч мөс чанаргүй!

41-Р БҮЛЭГ

Бурхан хүн дээр хэрхэн ажилладаг вэ? Чи үүнийг ойлгож авсан уу? Энэ чамд ойлгомжтой байна уу? Тэр чуулганд хэрхэн ажилладаг вэ? Чи эдгээрийн талаар юу гэж бодож байна вэ? Чи эдгээр асуултыг хэзээ нэгэн цагт бодож үзэж байсан уу? Бурхан чуулган дахь ажлаараа дамжуулан юунд хүрэхийг хүсдэг вэ? Энэ бүхэн чамд ойлгомжтой байна уу? Хэрвээ үгүй бол, чиний хийдэг бүхэн хий хоосон, үр ашиггүй! Эдгээр үг чиний зүрх сэтгэлд хүрсэн үү? Идэвхгүй ухарч няцах биш, идэвхтэй ахих төдий байснаар Бурханы хүслийг гүйцэлдүүлэх үү? Сохроор хамтран ажиллах хангалттай юу? Энэ үзэгдлийн талаар тодорхой ойлголтгүй байвал юу хийх хэрэгтэй вэ? Эрж хайхгүй байх нь зүгээр үү? Бурхан, “Би нэгэнтээ хүмүүсийн дунд агуу ажил хийсэн боловч тэд анзааралгүй, тиймээс Би үүнийг тэдэнд алхам алхмаар илчлэхийн тулд Өөрийн үгийг ашиглах хэрэгтэй болсон. Гэсэн ч хүн Миний үгийг ойлгоогүй бөгөөд Миний төлөвлөгөөний зорилгыг мэдэхгүй хэвээр үлдсэн юм” гэж хэлсэн. Эдгээр үг юу гэсэн утгатай вэ? Та нар энэ зорилгыг хэзээ нэгэн цагт эргэцүүлж үзсэн үү? Би зүгээр л зорилгогүйгээр, сохроор үүнийг хийсэн гэж үү? Хэрвээ тийм бол ямар хэрэгтэй юм бэ? Хэрвээ энэ зорилго нь чамд тодорхойгүй, ойлгомжгүй байвал хэрхэн жинхэнэ хамтын ажиллагаанд хүрэх билээ? Хүн төрөлхтний эрж хайж байгаа бүхэн нь зах хязгааргүй далайд, хоосон үгээр бичигдсэн сургаал дотор байдаг гэж Бурхан хэлдэг. Та нарын эрэл хайгуул

ямар ангилалд багтахыг ч чи тайлбарлаж чаддаггүй. Бурхан хүнд юу хэрэгжүүлэхийг хүсдэг вэ? Та нар энэ бүхний талаар тодорхой мэдэж байх ёстой. Энэ нь зөвхөн агуу улаан лууг сөрөг байдлаар шившиглэхийн төлөө байдаг уу? Агуу улаан лууг шившиг болгочхоод Бурхан зүгээр л гар хоосон ууланд гарч, ганцаараа амьдрах уу? Тэгвэл Бурханы хүсэж буй зүйл юу юм бэ? Тэр үнэхээр хүмүүсийн зүрх сэтгэлийг хүсдэг үү? Эсвэл тэдний амийг уу? Эсвэл тэдний эд баялаг, өмч хөрөнгийг үү? Эдгээр нь ямар хэрэгтэй юм бэ? Тэдгээр нь Бурханд ямар ч хэрэггүй. Бурхан хүнийг зүгээр л Сатаныг ялсныхаа баталгаа болгон ашиглаж, Өөрийнхөө “хүч чадлыг” харуулахын тулд хүн дээр маш ихийг хийсэн юм гэж үү? Энэ нь Бурханыг нэлээд “явцуу” харагдуулахгүй гэж үү? Бурхан үнэхээр тийм төрлийн Бурхан гэж үү? Насанд хүрэгчдийг өөр хооронд нь тэмцэлдүүлдэг хүүхэд шиг гэж үү? Энэ нь ямар ач холбогдолтой байна гэж? Хүн байнга өөрийн үзлээр Бурханыг хэмждэг. Бурхан нэгэнтээ “Жилд дөрвөн улирал байдаг, улирал бүрд гурван сар байдаг” гэж хэлсэн. Хүн эдгээр үгийг сонсож, ой ухаандаа шингээгээд нэг улиралд гурван сар, нэг жилд дөрвөн улирал байдаг гэж үргэлжлүүлэн хэлсээр байсан. Дараа нь Бурханыг “Жилд хэдэн улирал байдаг вэ? Бас нэг улиралд хэдэн сар байдаг вэ?” гэж асуухад хүмүүс нэгэн дуугаар “Дөрвөн улирал, гурван сар” гэж хариулсан. Хүн үргэлж дүрэм журам дээр үндэслэн Бурханыг тодорхойлохоор оролддог бөгөөд одоо “жилд гурван улирал, улиралд дөрвөн сар” байдаг эрин үед орчхоод хүн сохорсон мэт үүнийг мэдэхгүй хэвээр, бүх зүйлд дүрэм журам тогтоохоор оролдсоор байдаг. Тэгээд өнөөдөр хүн төрөлхтөн өөрийн “дүрэм журмыг” Бурханд хэрэглэхээр оролдож байна! Тэд үнэхээр сохор! Тэд одоо “өвөл” байхгүй, зөвхөн “хавар, зун, намар” байгааг харахгүй байна гэж үү? Хүн үнэхээр мулгуу! Одоогийн байгаа байдалдаа хүн Бурханыг хэрхэн мэдэх тухай ч мэдэхгүй хэвээр байгаа. Тэд яг л тээврийн хэрэгсэл тав тухгүй гэж боддог болохоор алхаж, эсвэл илжиг унадаг, эсвэл тосон дэнлүү буюу өөр хүй нэгдлийн үеийн амьдралын арга барил ашиглах ёстой гэж боддог 1920-оод оны хүмүүс шиг байдаг. Эдгээр нь бүгд хүмүүсийн тархинд оршдог үзэл биш гэж үү? Тэгвэл өнөөдөр яагаад өршөөл, хайр энэрлийн тухай ярьсаар байдаг юм бэ? Энэ нь ямар хэрэгтэй юм бэ? Үглээ эмгэн өнгөрснөө хүүрнэн өгүүлж байгаа юм шиг эдгээр үг ямар хэрэгтэй юм бэ? Эцсийн эцэст одоо үе бол одоо үе; цагийг 20 юм уу 30 жилээр ухрааж болох уу? Бүх хүн урсгалыг дагадаг; үүнийг хүлээн зөвшөөрөхөд тэдэнд яагаад ийм хэцүү байдаг юм бэ? Гэсгээлтийн өнөөгийн эрин үед өршөөл болон хайр энэрлийн тухай эдгээр яриа нь ямар хэрэгтэй юм бэ? Бурханд байдаг бүхэн нь зөвхөн өршөөл, хайр энэрэл юм гэж үү? Яагаад энэхүү “гурил, будааны” эрин үед хүмүүс “хивэг, зэрлэг хүнсний ногоогоор” үйлчилсээр байгаа юм бэ? Үүнийг Бурхан хийхийг хүсэхгүй дургүй байгаа ч хүн Түүнд хүчээр тулгадаг. Хэрвээ Тэр эсэргүүцэх юм бол Түүнийг “хувьсгалын эсэргүү” гэж хаяглах байсан бөгөөд Бурхан төрөлхөөсөө өршөөнгүй, энэрэнгүй биш гэдгийг ахин дахин хэлсэн ч гэсэн, хэн сонсдог гэж? Хүн дэндүү утгагүй. Бурханы үг ямар ч үр нөлөөгүй юм шиг байдаг. Хүн Миний үгийг үргэлж

өөр байдлаар хардаг. Бурхан гэмгүй хүмүүст үндэслэлгүйгээр хэрэг тохсон мэт хүмүүст үргэлж дээрэлхүүлдэг—тэгвэл хэн Бурхантай нэг санаа бодолтой байж чадах юм бэ? Та нар үргэлж Бурханы өршөөл, хайранд амьдрахыг хүсдэг, тиймээс Бурхан хүний доромжлолыг тэвчихээс өөр юу хийж болох вэ? Гэхдээ Бурхантай маргахаасаа өмнө та нар Ариун Сүнс хэрхэн ажилладгийг сайтар судлана гэж найдаж байна. Мөн Бурханы үгийн анхдагч утгыг анхааралтай харж үз гэж Би чамайг ятгаж байна. Бурханы үгийг “хольцтой” гэдэгт итгэн, өөрийгөө бүү ухаантайд тооц. Ингэх шаардлагагүй! Бурханы үг хэр их “хольцтойг” хэн хэлж чадах юм бэ? Бурхан үүнийг шууд хэлж, эсвэл үүнийг тодорхой дурдаагүй л бол тийм биш. Өөрийгөө хэтэрхий өндрөөр бүү бод. Хэрвээ Түүний үгээс хэрэгжүүлэлтийн замыг олж харж чадаж байвал Бурханы шаардлагад нийцсэн гэсэн үг. Чи өөр юу харахыг хүсэж байна вэ? Бурхан “Би хүний дорой мөхөс байдлыг цаашид огт өршөөхгүй” гэж хэлсэн. Энэхүү илэрхий, энгийн өгүүлэмжийн утгыг ч ойлгож чадахгүй бол цааш нь судалж, шинжлэх ямар хэрэгтэй юм бэ? Механикийн анхан шатны мэдлэггүйгээр чи пуужин бүтээхэд тохирно гэж үү? Тийм хүн зүгээр л бардамнах дуртай хүн биш гэж үү? Хүнд Бурханы ажлыг хийх нөөц бололцоо байхгүй; зүгээр л Бурхан тэднийг өргөмжилдөг юм. Түүний юунд дуртай эсвэл юуг үзэн яддагийг мэдэлгүйгээр зүгээр л Түүнд үйлчлэх нь гамшгийн урьтал биш гэж үү? Хүмүүс өөрсдийгөө ойлгодоггүй боловч өөрсдийгөө ер бусын гэж боддог. Тэд өөрсдийгөө хэн гэж бодоо вэ! Тэд сайн, муу гэж юу болох талаар юу ч мэддэггүй. Өнгөрснөө эргэн санаж, ирээдүйгээ урьдчилан хар—хэр сонсогдож байна даа? Үүний дараа өөрийгөө мэдэж ав.

Бурхан хүний санаа, зорилгын талаар асар ихийг илчилсэн. Бурхан: “Энэ үед л Би хүний санаа, зорилгыг тодорхой харсан юм. Би үүлэн дундаас ийнхүү шүүрс алдсан: Хүн яагаад үргэлж өөрийнхөө төлөө үйлддэг юм бэ? Миний гэсгээлт тэднийг төгс болгох учиртай биш гэж үү? Би тэдний эерэг хандлагыг албаар дараад байгаа гэж үү?” хэмээн хэлсэн. Эдгээр үгээс чи өөрийнхөө талаар хэр ихийг мэдэж авсан бэ? Хүний санаа болон зорилго үнэхээр алга болсон уу? Өөрөө шалгаж үзсэн үү? Бурханы өмнө очоод, үүнийг ойлгох гэж хичээсэн чинь дээр: Та нар дээр Бурханы хийсэн гэсгээлтийн ажил ямар үр дүнд хүрсэн бэ? Та нар үүнийг нэгтгэн дүгнэсэн үү? Магадгүй үр дүн нь өчүүхэн жаахан байх; тэрнээс биш чи аль хэдийн хэтрүүлэгтэйгээр ярьчихсан байх байсан. Бурхан та нарыг юунд хүргэсэн бэ? Та нарт хэлсэн олон үгээс хэр их нь хэрэгжиж, хэр их нь хий хоосон өнгөрсөн бэ? Бурханы нүдээр Түүний үгийн тун цөөхөн нь л хэрэгжсэн; учир нь хүн Түүний үгийн анхдагч утга учрыг хэзээ ч тайлж ойлгож чаддаггүй бөгөөд хананд ойсон үгсийн цуурайг л тэр хүлээн авдаг. Бурханы хүслийг мэдэх арга энэ гэж үү? Ойрын ирээдүйд, Бурханд хүнээр хийлгүүлэх илүү их ажил байх болно; хүн одоогийнх шигээ ийм жаахан биеийн хэмжээтэйгээр тэрхүү ажлыг биелүүлж чадах уу? Хазайж мурийхгүй бол алдаа гаргаж, эсвэл биеэ тоосон, ихэрхүү байх—хүмүүсийн уг чанар нэг иймэрхүү байдаг. Энэ нь үнэхээр ойлгохын аргагүй: Бурханы хэлсэн бүхнийг

хүн яагаад үнэн сэтгэлээсээ боддоггүй юм бэ? Бурханы үг ердөө хошигнож яриад, ямар нэг үр дүн эрэлхийлэхгүй байж таарах уу? Эсвэл хүнийг “Аз жаргал, Уур хилэн, Уй гашуу болон Баяр хөөр” гэсэн жүжигт тоглуулахын төлөө юм гэж үү? Хүнийг хэсэг зуур аз жаргалтай болгож, дараа нь уйлуулчхаад, дараагаар нь хүн тайзнаас буусан үед өөрөө өөрийгөө аргалах юм гэж үү? Үүний үр дүн нь юу байна гэж? “Хүнд тавьсан Миний шаардлага яагаад үргэлж талаар болдог вэ? Би нохойноос модонд авирахыг шаардаж байгаа мэт хэцүү зүйл шаардаад байгаа юм болов уу? Би хий дэмий юмны төлөө сүржигнээд байгаа юм болов уу?” Бурханы бүх үг хүний бодит байдалд чиглэдэг. Хүн бүрийн доторхыг харж, хэн Бурханы үгийн дагуу амьдарч байна гэдгийг харахад гэмгүй. “Одоо ч гэсэн газрын ихэнх хэсэг өөрчлөгдсөөр байна. Хэрвээ нэгэн өдөр газар дэлхий үнэхээр өөр төрлийнх болж өөрчлөгдвөл, Би үүнийг гараа хөдөлгөх төдийд л хөсөр хаях болно—энэ нь Миний одоогийн үе шатны ажил биш гэж үү?” Үнэндээ Бурхан одоо ч энэ ажлаа хийж байгаа; гэхдээ “гараа хөдөлгөх төдийд л хөсөр хаях болно” гэж хэлсэн нь ирээдүйн талаар хэлж байгаа. Учир нь бүх зүйлд үйл явц байх ёстой. Бурханы одоогийн ажил ийшээ зүглэж байгаа—ойлгомжтой байна уу? Хүний санаа зорилгод өө сэв байдаг бөгөөд бузар сүнснүүд энэ боломжийг ашиглан орж ирсэн. Энэ үед “газар дэлхий өөр төрлийнх болж өөрчлөгддөг.” Тэр үед хүмүүс чанарын өөрчлөлтөд орчихсон байх болно, гэхдээ тэдний мөн чанар хэвээрээ үлдэнэ. Учир нь сайжирсан газар дээр өөр зүйлс байна. Өөрөөр хэлбэл, анхдагч газар дорд чанартай байсан ба нэгэнт сайжирчихвал ашиглаж болох юм. Гэсэн хэдий ч, тодорхой хугацаанд ашиглагдаад, цаашид ашиглагдахаа больсны дараа энэ нь аажмаар хуучин дүр төрхөндөө буцаж орох болно. Энэ бол Бурханы ажлын дараагийн алхмын товч дүгнэлт юм. Бурханы ирээдүйн ажил илүү төвөгтэй, учир нь энэ бол бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах цаг байна. Төгсгөлийн уулзах газарт эмх замбараагүй байдал байх нь ойлгомжтой бөгөөд хүн хүчтэй итгэл үнэмшилгүй байх болно. Яг Бурханы хэлснээр: “Хүмүүс бүгд ямар ая тоглож байна тэрийг нь дагаж дуулдаг жүжигчид.” Хүмүүст ямар ая тоглож байна тэрийг нь дагаж дуулах чадвар байдаг болохоор Бурхан яг энэ өө сэвийг нь ажлынхаа дараагийн алхмыг хийхэд ашигладаг, ингэснээр Тэр бүх хүнийг энэхүү дутагдлаа өөрчлөхөд хүргэдэг. Хүмүүст жинхэнэ биеийн хэмжээ байдаггүй учраас тэд ханан дээр ургах өвс болдог. Хэрвээ тэд биеийн хэмжээ олж авсан бол тэнгэрт тулсан өндөр модод байх байсан. Бурхан хүн төрөлхтний нэг хэсгийг төгс болгохын тулд муу ёрын сүнсний ажлын нэг хэсгийг ашиглахаар зорьдог, ингэснээр энэ хүмүүс диаволуудын үйл хэргийг нэвт шувт бүрэн харж, бүх хүн төрөлхтөнд “өвөг дээдсээ” үнэхээр мэдэх боломжийг олгодог. Зөвхөн энэ аргаар хүмүүс бүрэн чөлөөлөгдөж, диаволуудын үр садыг байтугай өвөг дээдсийг нь ч хаядаг. Энэ нь агуу улаан лууг бүрэн ялах Бурханы жинхэнэ зорилго бөгөөд ингэснээр бүх хүн агуу улаан лууны жинхэнэ төрхийг мэдэж, үүний багийг бүрмөсөн хуулан хаяж, жинхэнэ төрхийг нь харах юм. Энэ нь Бурханы хүрэхийг хүсэж байгаа зүйл, энэ нь Түүний газар дээр хийсэн бүх

ажлын эцсийн зорилго бөгөөд бүх хүн төрөлхтөнд хэрэгжүүлэхийг зорьсон зүйл юм. Үүнийг Бурханы зорилгын төлөө бүх зүйлийг дайчлах гэж нэрлэдэг.

Ирээдүйн ажил хэрхэн хийгдэх талаар та нар тодорхой мэдэж байна уу? Энэ бүхнийг ойлгох ёстой. Жишээлбэл: Хүмүүс хийх ёстой зүйлээ хэзээ ч хийдэггүй гэж Бурхан яагаад хэлдэг юм бэ? Түүний өгсөн гэрийн даалгаврыг хийж дуусгаж чаддаггүй олон хүн байгаа гэж Тэр яагаад хэлдэг юм бэ? Эдгээр зүйлийг хэрхэн биелүүлэх вэ? Та нар эдгээр асуултыг хэзээ нэгэн цагт эргэцүүлэн үзэж байсан уу? Эдгээр нь нөхөрлөлийн чинь сэдэв болсон уу? Ажлын энэ үе шатанд хүнд Бурханы одоогийн санааг ойлгуулах ёстой. Нэгэнт үүнийг биелүүлчих юм бол бусдыг нь хэлэлцэж болно—ингэх нь сайн арга зам биш гэж үү? Бурханы хүнд хэрэгжүүлэхийг хүсэж байгаа зүйлийг ойлгомжтойгоор тайлбарлах хэрэгтэй, эс бөгөөс энэ бүгд нь хий дэмий болно. Хүн үүнд орох нь битгий хэл хэрэгжүүлж ч чадахгүй байх ба тэгвэл бүгд хий хоосон яриа болж дуусна. Бурханы өнөөдөр хэлсэн зүйлийг хэрэгжүүлэх замыг олсон уу? Хүмүүс Бурханы үгийг айдсын мэдрэмжтэйгээр хардаг. Тэд үүнийг бүрэн ойлгож чаддаггүй ч Бурханд халдахаас айдаг. Одоогоор Бурханы үгийг идэж, уух хэчнээн арга олчхоод байна вэ? Ихэнх хүн Бурханы үгийг хэрхэн идэж уухаа мэддэггүй; үүнийг яаж шийдвэрлэх вэ? Та нар өнөөдрийн үгийг идэж, уух арга олсон уу? Тэгэхдээ хамтран ажиллахаар чи одоо хэрхэн оролдож байна вэ? Та бүгд үгийг идээд, уучихсаныхаа дараа ямар аргаар тэдгээрийн талаарх өөрсдийн эргэцүүллээ хэлэлцэх вэ? Хүний хийх ёстой зүйл энэ биш гэж үү? Ямарваа нэг өвчинд хэрхэн зөв эмийн жор бичих вэ? Та нарт Бурхан шууд айлдвараа айлдах хэрэгтэй хэвээр үү? Энэ нь шаардлагатай юу? Өмнө дурдсан асуудлуудыг хэрхэн бүрэн арилгах вэ? Энэ нь та нар бодит үйл хэрэгтээ Ариун Сүнстэй хамтран ажиллаж чадах эсэхээс хамаарна. Хэрвээ тохиромжтой хамтын ажиллагаа байвал Ариун Сүнс агуу ажил хийх болно. Хэрвээ тохиромжтой хамтын ажиллагаа биш, харин төөрөгдөл байх юм бол Ариун Сүнс хүч чадлаа гаргах боломжгүй байна. “Хэрвээ чи өөрийнхөө дайсныг болон өөрийгөө мэдэж байх юм бол үргэлж ялалт байгуулах болно.” Эдгээр үгийг анх хэлсэн хүн хэн ч бай тэдгээр нь та нарын хувьд хамгийн тохиромжтой юм. Товчхондоо та нар, дайснаа мэдэж авахаасаа өмнө өөрсдийгөө эхлээд мэдэх ёстой бөгөөд аль алиныг нь мэдсэн цагт л та нар тулаан болгонд ялж чадна. Та нар бүгд үүнийг хийж чадах ёстой. Бурхан чамаас юу хүсдэг нь хамаагүй чи зүгээр л үүнд бүхнээ зориулах хэрэгтэй. Эцэст нь Бурханы өмнө ирээд бүхнээ зориулж чадна гэж найдаж байна. Бурхан сэнтий дээрээ суугаад бахдалтай инээмсэглэхийг харж чадвал энэ нь чиний үхлийн тогтсон цаг байлаа ч чи нүдээ анихдаа инээж, инээмсэглэх чадвартай байх ёстой. Чи газар дээр байх хугацаандаа Бурханы төлөө эцсийн үүргээ биелүүлэх ёстой. Өнгөрсөн үед Петр Бурханы төлөө уруугаа харан цовдлогдсон; гэхдээ чи эцэстээ Бурханыг сэтгэл хангалуун болгож, өөрийн бүх эрч хүчийг Бурханы төлөө шавхах ёстой. Бүтээгдсэн нэгэн Бурханы төлөө юу хийж чадах вэ? Иймээс Бурхан чамайг хүссэнээрээ ашиглахад зориулж хожимдохоосоо өмнө Бурханд өөрийгөө тушаах

хэрэгтэй. Бурханыг аз жаргалтай, сэтгэл хангалуун болгож л байвал Түүгээр хүссэн бүхнийг нь хийлгэ. Хүнд гомдоллох ямар эрх байгаа юм бэ?

42-Р БҮЛЭГ

Хүмүүс өнөөдрийн айлдвараас ямар нэгэн өөрчлөлт олж харсан эсэхийг Би мэдэхгүй. Зарим хүн багахныг харсан байж магадгүй ч итгэлтэйгээр хэлж зүрхэлдэггүй. Бусад нь юу ч ухаараагүй байх. Сарын арван хоёр, арван тав дахь өдрийн Бурханы айлдваруудын хооронд яагаад тийм их өөрчлөлт байна вэ? Та нар үүнийг тунгаан бодож үзсэн үү? Та нарын үзэл бодол юу вэ? Бурханы бүх айлдвараас та нар ямар нэгэн зүйл ухаарсан уу? Дөрөвдүгээр сарын хоёрны өдөр болон тавдугаар сарын арван тавны хооронд хийгдсэн үндсэн ажил юу байсан бэ? Хүмүүс өнөөдөр яагаад юу ч мэдэхгүй, толгой руугаа бороохойгоор цохиулсан мэт учраа олохоо больсон байдаг вэ? “Хаанчлалын хүмүүсийн шившигт явдал” гэсэн гарчигтай ямар ч булан өнөөдөр яагаад байдаггүй вэ? Дөрөвдүгээр сарын хоёрны болон дөрөвний өдөр Бурхан хүний байдлыг зааж үзүүлээгүй; үүний адилаар өнөөдрөөс хойших хэдэн өдөр Тэр хүмүүсийн байдлыг зааж үзүүлээгүй—яагаад энэ вэ? Энд тайлагдаагүй таавар гарцаагүй бий—яагаад 180 градусын эргэлт байсан бэ? Эхлээд Бурхан яагаад тэгж хэлсэн талаар бага зэрэг ярилцацгаая. “Шинэ ажил эхэлмэгц” хэмээн Бурханы шууд л хэлсэн эхний хэдэн үгийг харцгаая. Тус өгүүлбэр нь Бурханы ажил шинэ эхлэлд орсон, Тэр дахин нэгэнтээ шинэ ажил эхэлсэн гэсэн анхны дохиог чамд өгдөг. Энэ нь гэсгээлт дуусаж байгааг харуулдаг; гэсгээлтийн оргил үед аль хэдийн орсон гэж хэлж болох бөгөөд иймээс та нар ард хоцорч, эсвэл хаягдахгүй байхын тулд гэсгээлтийн энэ эриний ажлыг зохистой туулахад цагаа сайтар ашиглах ёстой. Эдгээр нь бүгд хүний ажил бөгөөд хамтран ажиллахын тулд чадах бүхнээ хийхийг хүнээс шаарддаг. Гэсгээлтийг бүрмөсөн дуусгасны дараа Бурхан Өөрийн ажлын дараагийн хэсгийг хийж эхэлдэг, учир нь Бурхан “… иймээс Би Өөрийн ажлыг хүмүүсийн дунд үргэлжлүүлэн гүйцэтгэсэн… Энэ мөчид Миний зүрх сэтгэл асар их баяр хөөрөөр дүүрэн байна, учир нь Би хэсэг хүмүүсийг олж авсан бөгөөд иймээс Миний ‘бизнес’ уналтад байхаа больж, хий хоосон үг байхаа больсон” гэсэн билээ. Урьдын цагт хүмүүс Бурханы үгээс Түүний яаралтай хүслийг харсан—үүнд ямар ч худал хуурмаг байгаагүй—өнөөдөр Бурхан Өөрийнхөө ажлыг улам их хурдтай хийдэг. Хүний хувьд энэ нь Бурханы шаардлагуудтай бүрэн нийцдэггүй мэт санагддаг—гэхдээ Бурханы хувьд Өөрийнх нь ажил аль хэдийн дуусчихсан. Хүмүүсийн бодол хэтэрхий ээдрээтэй учраас аливааг үзэх тэдний үзэл бодол дэндүү төвөгтэй байдаг. Хүмүүс хүмүүсээс хэтэрхий ихийг шаарддаг, гэвч Бурхан хүнд тийм өндөр шаардлага тавьдаггүй, ийм учраас Бурхан болон хүний хоорондын ялгаа хэчнээн их болохыг үүнээс харж болно. Хүмүүсийн үзэл Бурханы хийдэг бүхэнд ил болдог. Бурхан хүмүүст өндөр

шаардлага тавиад, хүмүүс тэдгээрийг нь биелүүлэх чадваргүй байдаг юм биш, харин хүмүүс Бурханд өндөр шаардлага тавьдаг ба Бурхан тэдгээрийг биелүүлж чаддаггүй. Учир нь, эмчилгээний дараа, хэдэн мянган жилийн турш Сатаны завхруулсан хүн төрөлхтөнд үр уршиг нь байдгийн улмаас хүмүүс Бурханд үргэлж тийм өндөр шаардлага тавьж, өчүүхэн төдий ч зөөлөн ханддаггүй, Бурхан дургүйцнэ гэдгээс ихэд айдаг. Тиймээс олон зүйл дээр хүмүүс даалгавар биелүүлж чадахгүй байх үедээ өөрсдийгөө гэсгээдэг; тэд үйлдлийнхээ үр дагаврыг үүрдэг—энэ нь жинхэнэ зовлон юм. Хүмүүсийн амссан зовлон бэрхшээлийн 99-өөс дээш хувийг нь Бурхан зэвүүцдэг. Шулуухан хэлэхэд, хэн ч Бурханы төлөө үнэхээр зовоогүй. Хүмүүс бүгдээрээ өөрсдийн үйлдлийн үр дагаврыг үүрдэг—гэсгээлтийн энэ алхам ч мэдээж ялгаагүй; энэ нь хүний хандалсан гашуун аяга бөгөөд өөрөө уухын тулд тэр үүнийг амандаа аваачдаг. Бурхан Өөрийн гэсгээлтийн жинхэнэ зорилгыг илчлээгүй учраас хэдийгээр хараагдсан хэсэг хүмүүс байдаг боловч энэ нь гэсгээлтийг төлөөлдөггүй. Хүмүүсийн зарим хэсэг нь ерөөгдсөн, гэхдээ энэ нь, тэд ирээдүйд ерөөгдөнө гэсэн үг биш юм. Бурхан бол хэлсэн амандаа хүрдэггүй Бурхан юм шиг хүнд санагддаг. Бүү санаа зов. Эдгээр нь бага зэрэг хэтрүүлэгтэй байж магадгүй, гэхдээ юмыг муугаар бүү бод; Миний хэлдэг зүйл хүний зовлонтой зарим талаар хамаатай байдаг ч чи Бурхантай сайн харилцааг бий болгох ёстой гэж Би бодож байна. Чи Түүнд илүү их “бэлэг” өгөх ёстой, тэр нь Түүнийг гарцаагүй баярлуулна. Өөрт нь “бэлэг” өгдөг хүмүүсийг Бурхан хайрладаг гэж Би итгэдэг. Чи юу гэж хэлэх вэ? Эдгээр үг зөв үү?

Одоо та нар хэтийн ирээдүйнхээ хэр ихийг хойш тавьсан бэ? Бурханы ажил удахгүй дуусах болно—иймээс та нар өөрсдийнхөө хэтийн ирээдүйн бараг бүгдийг хойш тавьсан байх ёстой, тийм үү? Та нар мөн өөрсдийгөө шинжилсэн байх: Та нар үргэлж өндөрт зогсож, өөрсдийгөө өргөмжилж, сайрхах дуртай—энэ чинь юу вэ? Өнөөдөр, хүмүүсийн хэтийн ирээдүй юу болохыг Би мэдэхгүй л байна. Хэрвээ хүмүүс үнэхээр шаналлын далайд залгигдан амьдардаг бол зовлон бэрхшээлийн цэвэршүүлэлт дунд, эсвэл тамлалын янз бүрийн хэрэгслийн заналхийлэл дор амьдарч, эсвэл бүх хүнд гологдох цаг үед амьдарч, тэнгэр өөд харж, гүнээ санаа алдах үедээ тэд бодол санаандаа хэтийн ирээдүйгээ хойш тавьдаг байж магадгүй юм. Учир нь хүмүүс мухардмал байдал дунд өөр ертөнцийн төгс сайхан газрыг эрж хайдаг бөгөөд тав тухтай нөхцөлд байдаг нэг ч хүн сайхан мөрөөдлийнхөө хойноос хөөцөлдөхөө хэзээ ч больж байгаагүй юм. Энэ нь бараг найдваргүй байж болох ч хүмүүсийн зүрх сэтгэлд ийм зүйл байхгүй байгаасай гэж Би хүснэ. Та нар амьд ахуйдаа өргөгдөхийг хүссээр байна уу? Та нар махан бие дэх хэлбэрээ өөрчлөхийг хүссээр байна уу? Та нар адилхан саналтай байгаа юу гэдгийг Би мэдэхгүй, гэхдээ Би үүнийг дандаа бүтэшгүй гэж санадаг—ийм бодол Надад хэрээс хэтэрсэн мэт санагддаг. Хүмүүс иймэрхүү зүйл хэлдэг: “Хэтийн ирээдүйгээ хойш тавь, илүү бодитой бай”. Ерөөгдөх бодлоосоо салахыг чи хүмүүсээс шаарддаг—тэгвэл чиний хувьд ямар вэ? Чи хүмүүсийн ерөөгдөх санаа бодлыг няцаадаг атлаа өөрөө ерөөл

эрж хайдаг уу? Бусад хүмүүс ерөөл хүлээн авахыг чи зөвшөөрдөггүй атлаа өөрөө тэдгээрийн талаар тувт нууцхан боддог—тэр нь чамайг юу болгож байна вэ? Залилан мэхлэгч! Тийнхүү үйлдэх үедээ мөс чанар чинь буруушаагдахгүй байна уу? Зүрх сэтгэлдээ өртэй мэт санагдахгүй байна уу? Чи хууран мэхлэгч биш гэж үү? Чи бусдын зүрх сэтгэлийн үгийг ухаж гаргадаг боловч өөртөө байгаа зүйлийн талаар юу ч хэлдэггүй—чи ямар хэрэггүй хог вэ! Ярих үедээ та нар зүрх сэтгэлдээ юу бодож байгаа бол гэж Би гайхдаг—та нарыг Ариун Сүнс зэмлэхгүй гэж үү? Энэ нь өөрийгөө хүндлэх хүндлэлийг чинь зовоодоггүй гэж үү? Өөрсдөд чинь юу сайн болохыг та нар үнэхээр мэддэггүй! Та нар бүгдээрээ Ноён Нангуотай яг адилхан—дүр үзүүлэгчид байсаар ирсэн. Бурхан, “хүмүүс бүгд ‘өөрсдийгөө зориулахад’ бэлэн байгаа” гэдгийн “өөрсдийгөө зориулах” гэсэн үгийг хашилтад хийсэнд гайхах юмгүй. Бурхан хүнийг арван хуруу шигээ мэддэг бөгөөд хүний заль мэх хэчнээн овжин байх нь хамаагүй—тэр санаагаа ил гаргахгүй, нүүр нь улайхгүй, зүрх нь хурдан цохилохгүй байсан ч гэсэн—Бурханы нүд хурц юм, иймээс хүний хувьд Бурханы харцнаас зугтах нь үргэлж төвөгтэй. Бурхан рентген хараатай бөгөөд хүний дотоод эрхтнүүдийг харж чаддаг мэт, хүмүүсийг нэвт хараад шинжилгээ хийлгүйгээр хүний цусны бүлгийг тогтоож чаддаг мэт байдаг. Бурханы мэргэн ухаан ийм бөгөөд үүнийг хүн дуурайж чадахгүй. Бурханы хэлснээр “Би маш их ажил хийсэн атал яагаад үүний баталгаа хүмүүст байдаггүй юм бэ? Би хангалттай хичээл чармайлт гаргаагүй гэж үү?” Хүний Бурхантай хамтрах хамтын ажиллагаа хэтэрхий дутмаг байдаг, хүний дотор хэтэрхий их сөрөг зүйл байдаг гэж хэлж болох ба хүмүүст эерэг байдал тун ховор байдаг. Тэд хааяа л бага зэрэг эерэг байвч тэр нь хэт бохирдсон байдаг. Хүмүүс Бурханыг яг хэр их хайрладгийг энэ нь харуулдаг; тэдний зүрх сэтгэлд Бурханыг гэсэн хайр ердөө зуун саяны нэг хувь байдаг бөгөөд үүний 50% нь бохирдсон байдаг. Тийм учраас хүнээс ямар ч баталгаа олж авдаггүй гэж Бурхан хэлсэн. Хүний дуулгаваргүй байдлын улмаас л Бурханы айлдваруудын өнгө аяс маш хатуу, цэвдэг байдаг. Хэдийгээр Бурхан хүнтэй улиран одсон үеийг ярилцдаггүй ч хүмүүс Бурханы өмнө өөрсдийгөө харуулахын тулд өнгөрснийг дурсан санахыг үргэлж хүсдэг, тэд улиран одсон үеийн тухай ярихыг үргэлж хүсдэг—гэсэн ч Бурхан хэзээ ч хүний өчигдрийг өнөөдөр мэт авч үзээгүй; харин Тэр өнөөдрийн хүмүүст өнөөдрийн нөхцөлөөр нь ханддаг. Энэ бол Бурханы хандлага бөгөөд хожим хүмүүс Бурхан хэтэрхий үндэслэлгүй гэж хэлэхээс сэргийлэхийн тулд Бурхан энд эдгээр үгийг тодорхой хэлсэн. Учир нь Бурхан мөс чанаргүй зүйл хийдэггүй, харин хүмүүст үнэн баримтуудын талаар хэлдэг, хүмүүс бат зогсож чадахгүй байх вий—учир нь эцсийн эцэст хүн бол сул дорой юм. Эдгээр үгийг сонсчхоод ингэвэл ямар вэ: Та нар сонсож, захирагдахад бэлэн байгаад харин энэ талаар дахин бодохгүй байна уу?

Дээрх зүйл нь сэдвээс гадуурх зүйл; үүнийг ярьсан уу, үгүй юү гэдэг нь хамаагүй. Та нарыг дургүйцэхгүй гэж Би найдаж байна, учир нь Бурхан энэхүү үгийн ажлыг хийдэг бөгөөд Тэр бүх л юмны тухай ярилцах дуртай. Гэхдээ та нар

тэдгээрийг уншиж, тэдгээр үгийг үл ойшоохгүй гэж Би найдаж байна. Та нар юу гэмээр байна? Тэгж чадах уу? Өнөөдрийн үгэнд Бурхан шинэ мэдээлэл илчилсэн гэж дөнгөж сая хэлсэн: Бурханы ажилладаг арга барил өөрчлөгдөх гэж байна. Тиймээс чухамхүү энэ тулгамдсан сэдэв дээр анхаарлаа төвлөрүүлсэн нь дээр. Өнөөдрийн бүх айлдвар нь ирээдүйн хэрэг явдлуудыг зөгнөсөн гэж болно; эдгээр айлдвар нь Бурхан Өөрийн ажлын дараагийн алхамд зохицуулалт хийж байгаа хэрэг юм. Бурхан чуулганы хүмүүс дэх Өөрийн ажлыг бараг дуусгасан бөгөөд үүний дараа Тэр бүх хүний өмнө уур хилэнтэйгээр гарч ирнэ. Бурханы хэлдгээр “Би газар дээрх хүмүүсээр Өөрийн үйлсийг хүлээн зөвшөөрүүлж, ‘шүүлтийн ширээний’ өмнө Миний үйл хэргүүд нотлогдоно, ингэснээр газар дэлхий даяар хүмүүсийн дунд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тэд бүгд бууж өгнө.” Та нар энэ үгээс ямар нэг зүйл харав уу? Энд Бурханы ажлын дараагийн хэсгийн хураангуй байна. Эхлээд Бурхан улс төрийн эрх мэдлийг барьдаг бүх манааны нохдыг чин үнэнээр итгүүлж, тэднийг дахин хэзээ ч байр суурийн төлөө тэмцэлдэж, дахиад хэзээ ч үгсэн хуйвалдаж, далд явуулга хийлгүй сайн дураараа түүхийн тавцангаас ухрахад хүргэнэ. Бурхан газар дээр янз бүрийн гай гамшиг бий болгосноор энэ ажил Бурханаар дамжин гүйцэтгэгдэх ёстой. Гэхдээ Бурхан огт гарч ирэхгүй. Энэ удаа агуу улаан лууны үндэстэн бузрын газар хэвээр байх учраас Бурхан гарч ирэхгүй, гэхдээ гэсгээлтээр дамжуулан илрэх болно. Тэр нь Бурханы зөвт зан чанар бөгөөд хэн ч үүнээс зугтаж чадахгүй. Энэ хугацаанд агуу улаан лууны үндэстэнд оршин суудаг бүхэн гай гамшиг амсана, энэ нь бас угаасаа газар дээрх хаанчлалыг (чуулганыг) багтаадаг. Энэ нь баримтууд гарч ирж байгаа үе бөгөөд иймээс үүнийг бүх хүн мэдэрч, хэн ч зугтаж чадахгүй. Үүнийг Бурхан урьдчилан тогтоосон. Ажлын яг энэ алхмаас л болж Бурхан “Одоо үе бол асар том төлөвлөгөөг хэрэгжүүлэх цаг” хэмээн хэлсэн юм. Учир нь ирээдүйд газар дээр нэг ч чуулган байхгүй байх ба гай гамшиг гарч ирсний улмаас хүмүүс өмнө нь юу хүлээж байгаа бол гэхээс өөрийг бодох чадваргүй болох ба гай гамшгийн дунд Бурханыг таашаах нь тэдэнд хэцүү байдаг. Тиймээс энэ гайхалтай цаг хугацаанд Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ хайрлахыг хүмүүсээс хүсдэг, ингэснээр тэд боломжийг алдахгүй юм. Энэ баримт улиран өнгөрөхөд Бурхан агуу улаан лууг бүрэн ялан дийлж, улмаар Бурханы ардуудын гэрчлэлийн ажил нь төгсгөл болсон байх болно; дараа нь Бурхан ажлын дараагийн алхмыг эхлүүлж, агуу улаан лууны орныг сүйрүүлж, эцэст нь орчлон ертөнц даяар хүмүүсийг уруу харуулж загалмайд цовдолно, үүний дараа Тэр бүх хүн төрөлхтнийг устгана—эдгээр нь Бурханы ажлын ирээдүйн алхмууд билээ. Тиймээс та нар энэхүү амар амгалан орчинд Бурханыг хайрлахаар оролдох ёстой. Хожим та нарт Бурханыг хайрлах ямар ч боломж байхгүй байх болно, учир нь махан биетэй байхдаа л хүмүүс Бурханыг хайрлах боломжтой байдаг; тэднийг өөр ертөнцөд амьдрах үед хэн ч Бурханыг хайрлах талаар ярихгүй. Энэ нь бүтээгдсэн зүйлийн хариуцлага биш гэж үү? Иймээс амьдралынхаа өдрүүдэд та нар Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Чи энэ талаар ер нь бодож байсан уу? Чи үхсэнийхээ дараа л

Бурханыг хайрлах гээд хүлээж байна уу? Энэ нь хоосон яриа биш гэж үү? Өнөөдөр яагаад чи Бурханыг хайрлахаар зорьдоггүй юм бэ? Завгүй байх зууpаа Бурханыг хайрлах нь Бурханыг гэсэн жинхэнэ хайр байж болох уу? Бурханы ажлын энэ алхам удахгүй төгсгөлдөө очно гэж хэлсний шалтгаан бол Сатаны өмнө Бурханд аль хэдийн гэрчлэл бий. Тиймээс ямар нэгэн зүйл хийх хэрэг хүнд байхгүй; амьд байгаа хугацаандаа Бурханыг хайрлахаар эрж хайхыг хүнээс хүсдэг төдий юм—энэ нь гол зүйл. Бурханы шаардлагууд өндөр биш учраас, түүнчлэн Түүний зүрх сэтгэлд тэсэхийн аргагүй түгшүүр байдаг учраас Тэр ажлын энэхүү алхам дуусахаас өмнө ажлын дараагийн алхмын хураангуйг илчилсэн ба энэ нь хэр их цаг үлдсэнийг тодорхой харуулдаг; хэрвээ Бурхан зүрх сэтгэлдээ түгшээгүй байсан бол эдгээр үгийг ийм эрт хэлэх байсан гэж үү? Цаг бачим учраас Бурхан ийм маягаар ажилладаг. Та нар яг л амиа нандигнадаг шигээ Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ, бүх оюун ухаанаараа, бүх хүч чадлаараа хайрлаж чадна гэж найдаж байна. Энэ нь хамгийн утга учиртай амьдрал биш гэж үү? Өөр хаанаас та нар амьдралын утга учрыг олох юм бэ? Чи маш сохор байгаа бус уу? Чи Бурханыг хайрлахад бэлэн байна уу? Бурхан хүний хайрыг хүртэх үнэ цэнтэй юу? Хүмүүс хүний бахдал бишрэлийг хүртэх үнэ цэнтэй юу? Тэгвэл чи юу хийх ёстой вэ? Бурханыг зоригтойгоор, бүхий л зүрх сэтгэлээрээ хайрла—тэгээд Бурхан чамд юу хийхийг хар. Тэр чамайг хөнөөх эсэхийг хар. Дүгнэж хэлэхэд, Бурханыг хайрлах үүрэг даалгавар нь Бурханы төлөө аливааг хуулж, бичихээс илүү чухал. Чи хамгийн чухал зүйлийг нэгдүгээрт тавих ёстой, ингэснээр чиний амьдрал илүү утга учиртай, аз жаргалаар дүүрэн болох бөгөөд дараа нь чи Бурханы чамд зориулсан “ялыг” хүлээх ёстой. Чиний төлөвлөгөө Бурханыг хайрлах явдлыг багтаах болов уу гэж Би гайхаж байна. Хүн бүхний төлөвлөгөө нь Бурханы биелүүлэх зүйл болж, бодит байдал болоосой гэж Би хүсэж байна.

44-Р БҮЛЭГ БА 45-Р БҮЛЭГ

Бурхан хүнд, бүх хичээлээс хамгийн гүн гүнзгий нь болох “Бурханыг хайрлах” талаар хэлснээсээ хойш “долоон Сүнсний айлдварууд” гэх энэ сэдвээр ярихад анхаарлаа төвлөрүүлэн, бүх хүнийг хүний амьдралын хоосон байдлыг мэдэхээр оролдоход хүргэж, улмаар тэдний доторх жинхэнэ хайрыг ухан гаргадаг. Тэгвэл өнөөгийн алхамд оршдог хүмүүс Бурханыг хэр их хайрладаг вэ? Та нар мэдэх үү? “Бурханыг хайрлах” хичээлд ямар ч хязгаар байхгүй. Хүний амьдралын талаар бүх хүн ямархуу мэдлэгтэй байдаг вэ? Бурханыг хайрлах талаар тэдний хандлага ямар байдаг вэ? Тэд хүсдэг үү, эсвэл хүсдэггүй юу? Тэд олон нийтийг дагадаг уу, эсвэл махан биеийг жигшдэг үү? Эдгээр нь та нарын тодорхой мэдэж, ойлгох ёстой бүх зүйл юм. Хүмүүсийн дотор үнэхээр юу ч байдаггүй гэж үү? “Хүн Намайг үнэхээр хайрлаасай гэж Би хүсдэг, гэвч өнөөдөр хүмүүс цаг нөхцөөсөөр жинхэнэ хайраа

Надад өгч чаддаггүй. Надад жинхэнэ хайраа өгчих юм бол өөрсдөө юу ч үгүй хоосон хоцорно гэж тэд төсөөлөлдөө боддог.” Эдгээр үгэн дэх “жинхэнэ хайр” гэдэг нь үнэндээ яг юу гэсэн үг юм бэ? “Бүх хүн Бурханыг хайрладаг” энэ эринд Бурхан яагаад хүмүүсийн жинхэнэ хайрыг шаардсаар байдаг юм бэ? Тиймээс Бурханы санаа зорилго бол хариултын хуудсан дээр жинхэнэ хайрын утгыг бичихийг хүнээс шаардах явдал тул энэ нь чухамдаа хүнд Бурханы даалгасан гэрийн даалгавар юм. Өнөөдрийн энэ алхмын тухайд бол, хэдийгээр Бурхан хүнд асар их шаардлага тавьдаггүй ч хүмүүс, хүнд тавьсан Бурханы анхдагч шаардлагад хараахан хүрээгүй; өөрөөр хэлбэл, тэд Бурханыг хайрлахад хамаг хүчээ хараахан зориулаагүй. Тиймээс энэ ажил үр дүнтэй болж, энэ ажлаар Өөрөө алдрыг олж авах хүртлээ Бурхан, хүмүүсийг хүсээгүй байхад нь Өөрийнхөө шаардлагыг тавьсаар байдаг. Үнэндээ газар дээрх ажил Бурханыг гэх хайраар төгсдөг. Тиймээс Бурхан Өөрийнхөө ажлыг төгсгөх үедээ л хамгийн чухал ажлыг хүнд заан үзүүлдэг. Өөрийнх нь ажил дуусах үед Тэрээр хүнд үхлийг өгвөл түүнд юу тохиолдох вэ, Бурхан яах вэ, мөн Сатан яах вэ? Газар дээрх хүний хайрыг гарган авах үед л “Бурхан хүнийг байлдан дагуулсан” гэж хэлж болно. Эс бөгөөс хүмүүс, хүнийг дээрэлхдэг болохоороо Бурхан ичдэг гэж хэлэх болно. Бурхан Өөрийн ажлыг ямар ч сураг чимээгүйгээр төгсгөл болгохуйц тийм тэнэг байна гэж үгүй. Тиймээс ажил удахгүй дуусах гэж байх үед Бурханыг хайрлах хүсэл тэмүүлэл бий болж, Бурханыг хайрлах нь чухал сэдэв болдог. Мэдээж Бурханыг хайрлах энэхүү хайранд хүний хольц байхгүй; энэ нь нөхрөө гэх үнэнч эхнэрийн хайр шиг, эсвэл Петрийн хайр шиг хольцгүй хайр юм. Бурхан Иов, Паул хоёрынх шиг хайрыг хүсдэггүй, харин Еховаг гэх Есүсийн хайр буюу Эцэг, Хүүгийн хоорондох хайрыг хүсдэг: “Хувийн ашиг, алдагдлыг бодохгүйгээр зөвхөн Эцэгийг бодож, өөр хэнийг ч биш зөвхөн Эцэгийг хайрлаж, өөр юу ч хүсэхгүй байх.” Хүн үүнийг биелүүлэх чадвартай юу?

Хэрвээ бүрэн хүн чанартай байгаагүй Есүсийн хийсэнтэй харьцуулбал бид юу боддог вэ? Та нар бүрэн хүн чанарааараа хаа хүрсэн бэ? Та нар Есүсийн хийсний аравны нэгд хүрч чадах уу? Бурханы төлөө загалмай руу явахад тохирох уу? Бурханыг гэх хайр чинь Сатанд ичгүүр авчирч чадах уу? Хүнийг хайрлах хайрынхаа хэр ихийг та нар арилгасан бэ? Үүнийг Бурханыг гэх хайраар орлуулсан уу? Та нар Бурханыг хайрлахын төлөө үнэхээр бүхнийг тэвчдэг үү? Өнгөрсөн үед амьдарч байсан Петрийн талаар түрхэн зуур бодоод, өнөөдрийн өөрсдийгөө хар—энд үнэхээр их ялгаа бий; та нар Бурханы өмнө зогсоход тохирохгүй. Та нарын дотор Бурханыг гэх хайр илүү их байна уу, эсвэл диаволыг гэх хайр илүү их байна уу? Үүнийг жингийн баруун, зүүн гар талд ээлжлэн тавиад аль нь илүү их байгааг харах ёстой—Бурханыг гэх хайр чинь үнэндээ хэр их байна вэ? Та нар Бурханы өмнө үхэхэд тохирох уу? Есүс загалмай дээр зогсож чадсаны шалтгаан нь газар дээрх Түүний туршлага Сатанд ичгүүр авчрахад хангалттай байснаас болсон бөгөөд зөвхөн тэр шалтгааны улмаас ажлын тухайн үе шатыг дуусгахыг Эцэг Бурхан Түүнд зоригтойгоор зөвшөөрсөн юм; энэ нь Түүний туулсан зовлон бэрхшээл болон

Бурханыг гэх хайраас нь болсон билээ. Гэхдээ та нар төдийлөн тохирдоггүй. Тиймээс үргэлжлүүлэн туршлагажиж, зүрх сэтгэлдээ өөр юуг ч биш, харин Бурханыг байлгадаг болох ёстой—ингэж чадах уу? Бурханыг хэр их үзэн яддагийг чинь болон Бурханыг хэр их хайрладгийг чинь үүнээс харж болно. Бурхан хүнээс хэтэрхий ихийг шаарддаг юм биш, харин хүн л шаргуу ажилладаггүй. Бодит нөхцөл байдал ийм байдаг бус уу? Хэрвээ ийм байгаагүй сэн бол чи Бурханаас хэр их хайр татам зүйл олж илрүүлж, өөрөөсөө хэр их жигшмээр зүйл олох байсан бол? Чи эдгээр зүйлийг сайтар бодолцож үзэх ёстой. Тэнгэрийн доор цөөн хэдэн хүн л Бурханыг хайрладаг гэж хэлэх нь зүйтэй юм—гэхдээ чи дэлхийн рекордыг эвдэж, Бурханыг хайрлах анхдагч нь байж чадах уу? Бурхан хүнээс юу ч шаарддаггүй. Хүн үүнийх нь төлөө Түүнд жаахан алдар хүнд өгч чадахгүй гэж үү? Бүр үүнийг ч гэсэн хийж чадахгүй гэж үү? Өөр ярих юм юу байгаа юм бэ?

46-Р БҮЛЭГ

Энэ бүх үгэн дундаас нэг нь ч өнөөдрийнхөөс илүү мартагдашгүй биш. Бурханы үг урьд нь хүний байр байдлыг, эсвэл тэнгэрийн нууцуудыг илчилсэн ч одоогийн энэхүү айлдвар өнгөрсөн үеийнхтэй адилгүй. Энэ нь дооглож, тоглоом тохуу хийдэггүй, харин тун гэнэтийн зүйл байдаг: Бурхан доош сууж, хүмүүстэй тайвнаар ярилцаж байгаа. Түүний санаа зорилго юу вэ? Бурханыг “Өнөөдөр Би орчлон ертөнцийн дээр шинэ ажил эхлүүлсэн. Би газар дээрх хүмүүст шинэ эхлэл өгч, Миний гэрээс нүүхийг тэднээс бүгдээс нь шаардсан. Хүмүүс үргэлж өөрсдийгөө өөгшүүлэх дуртай байдаг учраас ухамсартай байж, Миний ажлыг үргэлж үймүүлэхгүй байхыг Би тэдэнд зөвлөдөг” гэж хэлэх үед чи юу харсан бэ? Бурханы ярьдаг энэхүү “шинэ эхлэл” нь юу вэ? Бурхан өмнө нь хүмүүст явахыг зөвлөсөн боловч тухайн үед Бурханы санаа зорилго нь тэдний итгэлийг турших явдал байсан. Тэгвэл өнөөдөр өөр өнгө аясаар ярих үедээ Тэр чин сэтгэлээсээ байна уу, эсвэл худлаа юу? Урьд нь хүмүүс Бурханы ярьсан шалгалтуудыг мэддэггүй байсан. Зөвхөн үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхмаар л дамжуулан тэд Бурханы шалгалтуудыг нүдээрээ харж, биеэрээ амссан. Тиймээс тэр цагаас эхлээд Петрийн зуу зуун шалгалтуудын үлгэр жишээний ачаар хүмүүс үргэлж “энэ нь Бурханы шалгалт байсан” хэмээн итгэж алдаа гаргасан. Түүнчлэн, Бурханы үгэнд баримтууд тун ховорхон байсан. Тийм болохоор хүмүүс Бурханы шалгалтын тухай сохор итгэлд бүр ч их автсан тул Бурханы хэлсэн бүх үгийг Бурханы гүйцэтгэсэн бодит баримттай ажил гэж хэзээ ч бодоогүй; үүний оронд тэд, өөр хийх юмгүй Бурхан хүмүүсийг туршихын тулд үгийг тусгайлан ашиглаж байгаа гэж итгэсэн юм. Найдваргүй атлаа найдвар өгч байгаа мэт санагддаг тийм шалгалтуудын дунд хүмүүс дагасан болохоор “үлдсэн бүх хүн гарцаагүй сайнаасаа муу нь их байх болно” гэж Бурханыг хэлсний дараа ч дагахдаа л анхаарсаар байсан ба орхин явах

ямар ч санаагүй байсан. Хүмүүс тийм төөрөгдөл дунд дагасан бөгөөд ямар ч найдвар байхгүй гэдэгт тэдний нэг нь ч итгэлтэй байж зүрхлээгүй—энэ нь Бурханы ялалтын баталгааны нэг хэсэг юм. Тэр Өөртөө үйлчлүүлэхийн тулд бүх зүйлийг залж жолооддог гэдгийг Бурханы үзэл бодол харуулдаг. Хүмүүсийн төөрөгдөл нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран Бурханыг орхин явахгүй байхад тэднийг хүргэдэг, иймээс энэ алхмын үеэр Бурхан хүмүүсийн төгс бус сэдлийг ашиглан тэднээр Өөртөө гэрчлэл хийлгэдэг ба энэ нь “Би хэсэг хүмүүсийг олж авсан” гэж Бурханы хэлсний гүн гүнзгий ач холбогдол юм. Сатан үймээн үүсгэхийн тулд хүмүүсийн сэдлийг ашигладаг байхад Бурхан хүнээр үйлчлүүлэхийн тулд сэдлийг нь ашигладаг—энэ нь “хүмүүс яаж ийгээд орж чадна гэж төсөөлдөг боловч хуурамч орох тасалбаруудаа Надад өгөхөд нь Би тэр даруй гал руу шиддэг ба өөрсдийнх нь ‘уйгагүй хичээл чармайлт’ шатаж буйг хараад тэд итгэл найдвараа алддаг” хэмээх Бурханы үгийн жинхэнэ утга юм. Бурхан бүх зүйлээр үйлчлүүлэхийн тулд тэднийг залж жолооддог тул хүний янз бүрийн бодол санаанаас булталтаггүй ч хүмүүст яв гэж зоригтойгоор хэлдэг; үнэнч шударга үг болон арга барилыг хослуулах нь Бурханы ажлын гайхалтай байдал, мэргэн ухаан бөгөөд хүмүүсийг төөрөлдүүлж, толгойг нь эргүүлж орхидог. Бурхан Өөрийнх нь гэрээс нүүхийг хүмүүсээс үнэхээр шаардаж байгаа ба энэ нь нэг төрлийн шалгалт биш гэдгийг үүнээс харж болох бөгөөд Бурхан энэ боломжийг ашиглан “Гэхдээ Би бас хүмүүст, ерөөл хүртэж чадахгүй байх үедээ хэн ч Надад гомдоллож болохгүй гэж хэлсэн” гэдэг. Бурханы үг жинхэнэ, эсвэл худлаа эсэхийг хэн ч ухаарч чадахгүй, гэхдээ Бурхан энэ боломжийг ашиглан хүмүүсийг тогтвортой болгож, тэднийг явах хүсэлгүй болгодог. Тиймээс хэрвээ нэг л өдөр тэд хараагдвал Бурханы үг тэдэнд урьдчилан анхааруулсан байх бөгөөд хүмүүсийн хэлдгээр “сайн үг сонсоход хатуу боловч явдалд тустай” билээ. Өнөөдөр хүмүүс Бурханыг чин үнэнч сэтгэлээр хайрладаг учраас жинхэнэ үү, эсвэл худлаа юу гэдгийг нь ялгаж чадахгүй үгээр байлдан дагуулагдаж, Бурханыг хайрлах болсон, ийм учраас Бурхан “Би Өөрийн агуу ажлыг аль хэдийн гүйцэлдүүлсэн” гэж хэлсэн юм. Бурхан “Тэд амьд үлдэх замаа олно гэж Би найдаж байна. Энэ тухайд бол Би хүчин мөхөс” гэж хэлсэн нь Бурханы энэ бүх айлдварын бодит байдал юм—гэсэн ч хүмүүс тэгж боддоггүй; харин ч тэд үргэлж Бурханы үгэнд өчүүхэн төдий ч анхаарал хандуулалгүйгээр дагасан. Тийм болохоор Бурханыг “хожим нь бидний хоорондхамар ч үг байхаа больж, цаашид бидэнд ярилцах зүйл байхаа больж, бид нэг нэгэндээ саад болохгүй, тус тусынхаа замаар явна” гэж хэлэх үед эдгээр үг нь бодит байдал бөгөөд өчүүхэн төдий ч хольцгүй юм. Хүмүүс юу ч гэж боддог бай, энэ нь Бурханы “бодлогогүй” байдал юм. Бурхан аль хэдийн Сатаны өмнө гэрчлэл хийсэн бөгөөд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран бүх хүнийг Өөрийг нь орхин явахгүй байхад хүргэнэ гэж хэлсэн—иймээс ажлын энэ алхам гүйцэлдсэн ба Бурханы хүний гомдлыг огт анхаардаггүй. Гэхдээ Бурхан анхнаасаа үүнийг тодорхой хэлсэн учраас хүмүүс яах ч аргагүй болж, арга буюу ууран барьж, амаа хамхисан. Бурхан,

Сатан хоёрын хоорондох тулаан бүхэлдээ хүн дээр тулгуурладаг. Хүмүүс өөрсдийгөө хянаж чаддаггүй; тэд бол үнэхээр жинхэнээсээ утсан хүүхэлдэй бөгөөд Бурхан Сатан хоёр хөшигний араас утсыг нь татаж байдаг. Бурхан хүмүүсийг ашиглан Өөртөө гэрчлэл хийлгэх үедээ тэднийг Өөртөө үйлчлэл хийлгэхээр ашиглахын тулд боломжтой бүхнийг хийдэг бөгөөд хүмүүсийг Сатанаар удирдуулж, түүнчлэн Бурханаар зааварчлуулахад хүргэдэг. Бурханы хийхийг хүссэн гэрчлэл дуусах үед Тэр хүмүүсийг нэг тийш чулуудаж, тэднийг зовоон орхихын сацуу Өөрөө тэдэнтэй ямар ч хамаагүй мэт авирладаг. Хүмүүсийг ашиглахыг дахин хүсэх үедээ Тэр тэднийг дахин нэгэнтээ авч, ашигладаг—хүмүүс үүнийг өчүүхэн төдий ч мэддэггүй. Тэд зүгээр л эзэн нь дураараа ашигладаг үхэр, адуу шиг байдаг бөгөөд тэдний нэг нь ч өөрсдийгөө захирч чаддаггүй. Энэ нь бага зэрэг гунигтай сонсогдож болох ч хүмүүс өөрсдийгөө захирч чадах эсэхээс үл хамааран Бурханд үйлчлэл үзүүлэх нь сэтгэл гонсойхуйц зүйл биш, харин нэр төрийн хэрэг юм. Бурхан ийм маягаар үйлдэх учиртай мэт байдаг. Төгс Хүчитийн хэрэгцээг хангаж чаддаг байх нь бахархах зүйл биш гэж үү? Чи юу гэж бодож байна вэ? Чи Бурханд үйлчлэл үзүүлэх шийдвэрээ ер нь гаргасан уу? Өөрийнхөө хувийн эрх чөлөөг хайх эрхтэй байхыг чи хүссээр байгаа юм гэж үү?

Ямартай ч Бурханы хийдэг бүхэн сайн, дуурайваас зохилтой бөгөөд эцсийн эцэст хүн Бурхан хоёр өөр юм. Энэ үндсэн дээр, Бурхан чиний хайрыг анхааран үзэх эсэхээс үл хамааран чи Бурханыг хүний зүрх сэтгэлээр хайрлах ёстой. Бурханы зүрх сэтгэлд бас асар их уйтгар гуниг байдгийг Бурханы үг харуулдаг. Бурханы үгийн улмаас л хүмүүс цэвэршүүлэгддэг. Гэсэн ч эцсийн эцэст энэ ажил нь өчигдөр тохиолдсон—тэгвэл Бурхан дараа нь яг юу хийх вэ? Өнөөдрийг хүртэл энэ нь нууц хэвээр үлдсэн, тиймээс хүмүүс үүнийг ойлгож, ухаарч чаддаггүй бөгөөд Бурханы хөгжмийн аясаар л дуулахаас өөр аргагүй байдаг. Гэсэн хэдий ч Бурханы хэлдэг бүхэн бодитой бөгөөд бүгд биелдэг—энэ бол гарцаагүй!

ГУРАВДУГААР ХЭСЭГ

ЧУУЛГАНУУДААР ЯВАХДАА ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ

(1992 ОНЫ 6-Р САР—2010 ОНЫ 3-Р САРЫН 23)

ОРШИЛ

Бурханы үгийн энэ хэсэг нь нийт дөрвөн хэсэгтэй ба 1992 оны 6-р сараас 2010 оны 3-р сарын 23-ны хооронд Христ бүгдийг нь илэрхийлжээ. Эдгээрийн ихэнх нь чуулганууд аар явах зууpаа Христийн хийсэн нөхөрлөл, номлолын бичлэгүүдэд үндэслэдэг. Тэдгээрийг ямар нэгэн байдлаар засварлаагүй, мөн Христ ч дараа нь өөрчлөөгүй. Үлдсэн хэсгийг нь Христ биечлэн бичсэн юм (Христ бичих үедээ бодолгүйгээр, ямар нэг засвар хийлгүйгээр нэг дор бичсэн бөгөөд Түүний үг бол тэр чигтээ Ариун Сүнсний илэрхийлэл юм—энэ нь эргэлзээгүй). Энэ хоёр төрлийн айлдварыг салгахын оронд бид тэдгээрийг илэрхийлэгдсэн анхны дарааллаар нь хамтад нь толилуулсан; энэ нь бидэнд, Түүний бүх айлдвараас Бурханы ажлын алхмуудыг харж, үе шат бүрд Бурхан хэрхэн ажилладгийг ойлгох боломж олгодог бөгөөд Бурханы ажлын алхмууд болон Бурханы мэргэн ухааны талаарх хүмүүсийн мэдлэгт ач тустай байдаг.

“Чуулганууд аар явахдаа Христийн хэлсэн үг I”-ийн эхний найман бүлэг буюу нийтэд нь “Зам” хэмээдэг хэсэг нь Христийн, хүнтэй нэг түвшинд зогсож байгаад айлдсан үгийн цөөн хэсэг юм. Тэдгээр нь гаднаа онцын зүйлгүй мэт байдаг хэдий ч хүн төрөлхтнийг гэх Бурханы хайр, халамжаар бялхаж байдаг. Үүнээс өмнө Бурхан гуравдагч тэнгэрийн өнцгөөс үг хэлж, хүн Бурхан хоёрын хооронд асар их зай үүсгэсэн бөгөөд хүмүүсийг амийн хангалтыг Бурханаас гуйх нь бүү хэл, Бурханд ойртохоос ч айж эмээдэг болгосон юм. Тиймээс “Зам”-д Бурхан хүнтэй эн тэнцүү ярьж, замын чиглэлийг зааж, улмаар Бурхантай харилцах хүний харилцааг анхдагч байдалд нь сэргээсэн; Бурхан үг хэлэх арга ашигласаар байгаа эсэхэд хүмүүс эргэлзэхээ больж, үхлийн шалгалтаас айх айдаст автахаа больсон юм. Бурхан гуравдагч тэнгэрээс газар луу буун ирж, бас хүмүүс гал болон хүхэрт нуураас Бурханы сэнтийн өмнө ирж, “үйлчлэл үзүүлэгч”-дийн сүүдрийг хөсөр хаяад, дөнгөж төрсөн тугал адил Бурханы үгийн баптисмыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн юм. Тэр үед л Бурхан тэдэнтэй дотночлон ярилцаж, тэднийг амиар хангах ажил илүү ихийг хийж чадсан билээ. Бурхан Өөрийгөө хүн болгон дорд болгосны зорилго нь хүмүүстэй илүү ойр дотно болж, хүн Бурхан хоёрын хоорондох зайг багасгаж, хүмүүст хүлээн зөвшөөрөгдөж, итгэлийг нь олж аваад, амийг эрэлхийлж, Бурханыг дагах итгэлийг нь зоригжуулахын төлөө байв. “Зам”-ын найман бүлгийг хүмүүсийн зүрх сэтгэлийн үүдийг нээдэг Бурханы түлхүүр хэмээн дүгнэж болох бөгөөд тэдгээр нь нийтдээ Бурханы хүнд өгдөг чихрээр бүрсэн эмийг бүрдүүлдэг. Бурхан ийнхүү үйлдсэнээр л хүмүүс Бурханы удаа дараагийн сургаал, сануулгыг сайтар анхаарч чаддаг. Үүний дараа л Бурхан үргэлжлүүлэн “Итгэгчид ямар үзэл бодолтой байх учиртай вэ”, “Бурханы ажлын алхмуудын тухай” … зэргийг айлдсанаар одоогийн ажлын энэ үе шатны амиар хангаж, үнэнийг илэрхийлэх ажлыг албан ёсоор эхэлсэн гэж хэлж болно. Ийм арга барил нь Бурханы мэргэн ухаан, чин санаа зорилгыг харуулдаггүй гэж үү? Энэ нь Христийн хамгийн эхний амийн хангалт тул

дараагийн хэсгүүдтэй харьцуулахад үнэн нь арай өнгөц байдаг. Үүний цаад зарчим тун энгийн: Бурхан хүн төрөлхтний хэрэгцээнд тааруулж ажилладаг. Тэрээр сохроор үйлдэж, үг хэлдэггүй; хүн төрөлхтний хэрэгцээг Бурхан л бүрэн ойлгодог ба хүнийг гэх илүү их хайр, ойлголцол өөр хэнд ч үгүй.

“Ажил ба оролт”-ын нэгээс арав хүртэлх айлдварт Бурханы үг шинэ шатанд орсон байдаг. Тийм болохоор эдгээр айлдварыг эхэнд тавьсан юм. Дараа нь “Чуулганууд аар явахдаа Христийн хэлсэн үг II” бий болжээ. Энэхүү шатанд Бурхан дагалдагчдадаа илүү нарийн шаардлага тавьсан ба үүнд хүмүүсийн амьдралын хэв маягийн тухай мэдлэг, тэдний хэв чанарт тавих шаардлага гэх мэт шаардлагууд багтдаг. Энэ хүмүүс Бурханыг дагахаар шийдсэн, Бурханы ялгамж чанар, мөн чанарын талаар ямар ч эргэлзээ тээхээ больсон учраас Бурхан ч бас тэднийг Өөрийнх нь гэр бүлийн гишүүд гэж албан ёсоор авч үзэж эхлэн, бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэлх Бурханы ажлын дотоод үнэнийг нөхөрлөж, Библийн цаад нууцыг илчилж, Бурхан бие махбодтой болохын жинхэнэ ач холбогдлыг зааж сургажээ. Энэ хэсэгт буй Бурханы айлдварууд хүмүүст Бурханы мөн чанар болон Бурханы ажлын мөн чанарын талаар илүү сайн ойлгуулж, Бурханы авралаас хүртсэн зүйл нь өнгөрсөн эрин үеүдийн туршид эш үзүүлэгч, элчүүдийн олж авснаас давсан гэдгийг ухаарах боломж олгосон юм. Бурханы үгийн мөр болгоноос чи Түүний мэргэн ухааны өчүүхэн хэсэг бүрийг, мөн түүнчлэн хүнийг гэх өө сэвгүй хайр, халамжийг нь ухамсарлаж чадна. Эдгээр үгийг илэрхийлэхийн сацуу Бурхан хүний урьдын үзэл, төөрөгдөл, хүмүүсийн урьд нь хэзээ ч төсөөлж байгаагүй зүйлсийг болон ирээдүйд алхах замыг нэг нэгээр нь ил тод илчилсэн билээ. Магадгүй энэ нь хүмүүсийн мэдэрч чадах яг тэр явцуу “хайр” байх! Эцсийн эцэст Бурхан хэрэгтэй бүхнийг нь хүмүүст өгсөн бөгөөд юуг ч үлдээлгүйгээр, хариуд нь юу ч шаардалгүйгээр хүссэн бүхнийг нь өгсөн юм.

Энэ хэсэгт буй хэд хэдэн тодорхой бүлэг нь Библийн тухай өгүүлдэг. Библи хэдэн мянган жилийн турш хүний түүхийн нэг хэсэг байсаар ирсэн. Түүнчлэн, хүмүүс Библид Бурхан мэт хандаж, эцсийн өдрүүдэд энэ нь Бурханы орыг эзлэхдээ тулсан бөгөөд Бурхан энийг нь үзэн яддаг. Тиймээс цаг гарах үед, Библийн дотоод түүх болон эх үүсвэрийг тодруулах ёстой гэж Бурханд санагджээ; тэгэхгүй бол Библи хүмүүсийн зүрх сэтгэл дэх Бурханы байр суурийг эзэлсээр байх бөгөөд хүмүүс Библийн үгийг ашиглан Бурханы үйл хэргийг хэмжиж, яллах байв. Библийн мөн чанар, бүтэц, өө сэвийг тайлбарласнаараа Бурхан Библийн оршин тогтнолыг яавч үгүйсгээгүй, мөн үүнийг яллаа ч үгүй; харин ч Тэрээр Библийн анхдагч дүр төрхийг сэргээсэн зохистой, тохиромжтой тодорхойлолтыг өгч, Библид хандах хүмүүсийн буруу ойлголтыг хөндөж, Библийн талаарх үнэн зөв үзэл бодлыг өгсөн, ингэснээр тэд Библийг шүтэхээ больж, төөрөлдөхөө больсон; өөрөөр хэлбэл, тэд Библид итгэх сохор итгэлээ Бурханд итгэж, Бурханыг шүтэн мөргөж байгаа хэрэг хэмээн андуурахаа болиод, Библийн цаад үнэн түүх болон ташаарлуудтай нүүр тулахаас ч айдаг болсон. Хүмүүс Библийн талаар хольцгүй ойлголттой болмогцоо

ямар ч гэмшилгүйгээр үүнийг хөсөр хаяж, Бурханы шинэ үгийг зоригтойгоор хүлээн авч чаддаг. Энэ бол энэхүү хэдэн бүлэг дэх Бурханы зорилго билээ. Бурханы өнөөдрийн ажил болон үгийг ямар ч онол юм уу баримт орлож чадахгүй, Бурханы орыг юу ч эзэлж чадахгүй хэмээх үнэнийг Бурхан энд хүмүүст хэлэхийг хүсдэг. Хэрвээ хүмүүс Библийн урхинаас зугтаж чадахгүй бол Бурханы өмнө очиж хэзээ ч чадахгүй. Хэрвээ тэд Бурханы өмнө очихыг хүсвэл Түүнийг орлож чадах аливаа зүйлээс зүрх сэтгэлээ эхлээд цэвэрлэх ёстой; тэгвэл тэд Бурханы сэтгэлд нийцнэ. Хэдийгээр Бурхан энд Библийг л тайлбарласан боловч Библиэс гадна хүмүүсийн үнэн сэтгэлээсээ шүтдэг өөр олон эндүү ташаа зүйл байдаг гэдгийг бүү март; жинхэнээсээ Бурханаас ирдэг зүйлсийг л тэд шүтдэггүй юм. Бурхан хүмүүст буруу замаар бүү яв, Бурханд итгэж, Түүний үгийг хүлээн зөвшөөрөхдөө битгий дахин туйлшир, бүү төөрөлдөж будил гэж санаулахын тулд л Библийг жишээ болгон ашигладаг төдий юм.

Хүнийг хангадаг Бурханы үг өнгөцхөнөөс гүн гүнзгий болдог. Түүний айлдварын сэдвүүд хүмүүсийн гаднах зан авир, үйлдлээс эхлээд завхарсан зан чанарыг нь хүртэл шат дараатай үргэлжилдэг бөгөөд тэндээс Бурхан үг хэлнийхээ үзүүрийг хүмүүсийн сэтгэлийн хамгийн гүн гүнзгий хэсэг буюу гол чанар луу нь чиглүүлдэг: “Чуулгануудаар явахдаа Христийн хэлсэн үг III”-ийг илэрхийлж байх хугацаанд Бурханы айлдварууд нь хүний мөн чанар ба ялгамж чанар болон Жинхэнэ хүн байхын утга учрыг буюу хүмүүсийн амийн оролттой холбоотой эдгээр гүн гүнзгий үнэн болон амин чухал асуултуудыг онцолсон юм. Мэдээж “Чуулгануудаар явахдаа Христийн хэлсэн үг I”-д буй, Бурханы хүнд өгсөн үнэнийг эргээд бодвол “Чуулгануудаар явахдаа Христийн хэлсэн үг III” дахь агуулга харьцангуй, ер бусын гүн гүнзгий байдаг. Энэхүү хэсэг дэх үгс хүмүүсийн хожмын зам болон тэд хэрхэн төгс болгуулж чадах талаар хөнддөг; тэдгээр нь бас хүн төрөлхтний хожмын хүрэх газар болон Бурхан хүн хоёр хэрхэн хамтдаа амралтад орох талаар ч хөнддөг. (Хүмүүсийн гол чанар, үүрэг даалгавар, хүрэх газрын талаар Бурханы хүмүүст өнөөг хүртэл илэрхийлсэн, үгсээс эдгээр үг ойлгоход хамгийн амархан нь юм гэж хэлж болно.) Эдгээр үгийг уншдаг хүмүүс бол хүний үзэл, төсөөллөөс ангижирсан, Бурханы үг бүрийг зүрх сэтгэлийнхээ гүнд зөвөөр ойлгож чадах хүмүүс мөн гэж Бурхан найддаг. Түүнчлэн, эдгээр үгийг уншдаг бүх хүн Түүний үгийг үнэн, зам, амь хэмээн авч үзээд, Бурханы үгэнд хөнгөн хандахгүй, эсвэл Өөрийг нь аргацаахгүй гэж Тэр найддаг. Хэрвээ хүмүүс Бурханыг шинжилж, нягтлах хандлагаар эдгээр үгийг уншдаг бол эдгээр айлдвар нь тэдний хувьд хаалттай ном шиг байх болно. Үнэнийг эрэлхийлдэг, Бурханыг дагахаар шийдсэн, Түүнд өчүүхэн төдий ч эргэлздэггүй хүмүүс л эдгээр үгийг хүлээн авах эрхтэй билээ.

“Чуулгануудаар явахдаа Христийн хэлсэн үг IV” нь “Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдварууд”-ын дараах өөр нэг төрлийн бурханлаг айлдвар юм. Энэ хэсэг нь Христийн шашны урсгал дахь хүмүүст хандсан, “Есүсийн сүнслэг биеийг харах үед чинь Бурхан тэнгэр, газрыг шинээр бүтээсэн байх болно,”

“Христтэй нийцдэггүй хүмүүс гарцаагүй Бурханыг эсэргүүцэгчид юм” гэх мэт Бурханы ятгалга, сургаал, илчлэлийг агуулдаг. Энэ нь бас “Хүрэх газрынхаа төлөө хангалттай сайн үйл бэлд,” “Гурван сануулга,” “Гэм буруу нь хүнийг там руу хөтөлнө” гэх зэрэг хүн төрөлхтөнд тавих Бурханы хамгийн тодорхой шаардлагуудыг агуулдаг. Төрөл бүрийн хүмүүсийн илчлэл, шүүлт болон Бурханыг хэрхэн мэдэх тухайд хэлсэн үгс гэх мэт олон талыг хамардаг. Энэхүү хэсэг нь хүн төрөлхтнийг шүүх Бурханы шүүлтийн гол цөм юм гэж хэлж болно. Энэ бүлэг Бурханы айлдваруудаас хамгийн мартагдашгүй хэсэг нь Бурхан ажлаа дуусгах гэж байх үедээ хүмүүсийн бүр ясанд нь шингэсэн зүйл болох урвалтыг ил болгосон явдал юм. Түүний зорилго бол хэчнээн удаан хугацаанд Бурханыг дагасан чинь хамаагүй, уг чанар чинь Бурханаас урвадаг хэвээр байгаа гэх баримтыг хүмүүст бүр эцэст нь мэдэгдэж, үүнийг тэдний зүрх сэтгэлийн гүнд шингээх юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн амь туйлын төлөвшилтөд хүрч чаддаггүй, зан чанарт нь л харьцангуй өөрчлөлт гарч болдог учраас Бурханаас урвах гэдэг нь хүний уг чанарт байдаг билээ. Хэдийгээр “Урвалт 1”, “Урвалт 2” хэмээх энэ хоёр бүлэг нь хүмүүст цохилт өгдөг ч үнэндээ хүмүүст Бурханы өгсөн хамгийн үнэнч, сайхан сэтгэлийн анхааруулга юм. Ядаж л хүмүүс маадгар, ихэрхүү байх үедээ энэ хоёр бүлгийг уншаад хорон муу байдлаа хязгаарлаж, тайван болно. Энэ хоёр бүлгээр дамжуулан Бурхан, амь чинь хэчнээн төлөвшсөн, туршлага чинь хэчнээн гүн гүнзгий, өөртөө итгэх итгэл чинь хэр их байх нь хамаагүй, хаана төрсөн, хаашаа явж байгаагаас чинь үл хамааран Бурханаас урвах уг чанар чинь хэдийд ч, хаана ч гарч ирэх боломжтой гэдгийг бүх хүнд сануулдаг. Бурханаас урвах нь хүн нэг бүрийн төрөлх уг чанар юм гэдгийг Бурхан хүн болгонд хэлэхийг хүсдэг. Мэдээж, энэ хоёр бүлгийг илэрхийлэх Бурханы санаа зорилго нь хүн төрөлхтнийг таягдан хаях юм уу яллах шалтаг олохын төлөө биш, харин хүмүүсийг Бурханы удирдамжийг хүлээн авахын тулд цаг үргэлж Бурханы өмнө анхааралтай амьдарч чаддаг болгохын тулд тэдэнд хүний уг чанарыг илүү их мэдүүлэх зорилготой байдаг бөгөөд энэ нь хүмүүсийг Бурханы өмнө байхаа больж, эргэлт буцалтгүй замд хөл тавихаас нь болиулна. Энэ хоёр бүлэг нь Бурханыг дагадаг бүх хүний хувьд түгшүүрийн хонх юм. Хүмүүс Бурханы чин санаа зорилгыг ойлгоно гэж найдъя; эцсийн эцэст эдгээр үг бол бүгд маргашгүй баримт—тэгвэл тэдгээрийг Бурхан хэзээ, хэрхэн илэрхийлсэн талаар маргалдах ямар хэрэгтэй юм бэ? Хэрвээ Бурхан энэ бүх зүйлийг Өөртөө хадгалаад, Түүнийг эдгээрийг айлдахад тэнцэнэ гэж хүмүүсийг бодох хүртэл хүлээсэн бол хэтэрхий оройтох байсан бус уу? Хамгийн тохиромжтой цаг хэзээ байх юм бэ?

Энэ дөрвөн хэсэгт Бурхан олон янзын арга барил, өнцөг ашигладаг. Жишээ нь, заримдаа Тэр хошигнол ашиглаж, заримдаа шууд хангалт, сургаалын арга ашигладаг; заримдаа жишээ ашиглаж, заримдаа хатуу зэмлэл ашигладаг. Ерөнхийдөө, төрөл бүрийн өөр өөр арга барил байдаг ба энэ нь хүмүүсийн олон янзын байр байдал, дур сонирхолд тааруулах зорилготой юм. Түүний айлдварын өөр өөр арга барил, агуулгаас үүдэн үг хэлдэг өнцөг нь өөрчлөгддөг. Жишээлбэл, заримдаа Тэр “Би”,

эсвэл “Намайг” гэж хэлдэг; өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн өнцгөөс хүмүүстэй ярьдаг. Заримдаа гуравдагч хүний өнцгөөс ярьж, “Бурхан” бол ийм, тийм гэж хэлдэг, мөн заримдаа хүний өнцгөөс ярих үе байдаг. Тэр ямар өнцгөөс ярих нь хамаагүй, Түүний мөн чанар өөрчлөгддөггүй, учир нь Тэр яаж ч ярилаа гэсэн, илэрхийлдэг бүхэн нь Бурханы Өөрийн мөн чанар юм—энэ нь бүгд үнэн бөгөөд хүн төрөлхтөнд хэрэгтэй зүйл билээ.

ЧУУЛГАНУУДААР ЯВАХДАА ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ

I

(1992 ОНЫ 6-Р САР—1992 ОНЫ 10-Р САР)

ЗАМ… 1

Амьдрах хугацаандаа ямар бүтэлгүйтэлтэй тулгарахаа хэн ч мэддэггүй, ямар төрлийн цэвэршүүлэлтэд өртөхөө ч мэддэггүй. Энэ нь зарим хүний ажил, заримынх нь хэтийн ирээдүй, заримынх нь төрсөн гэр бүл, мөн заримынх нь гэрлэлтэд тулгардаг. Гэвч тэднээс ялгаатай нь энэ бүлэг хүмүүс бид өнөөдөр Бурханы үгэн дунд зовж байна. Өөрөөр хэлбэл, Бурханд үйлчилдэг хүмүүсийн хувиар бид Түүнд итгэх замдаа бүтэлгүйтэл амссан бөгөөд энэ нь бүх итгэгчийн явдаг зам, бид бүгдийн хөл доорх зам юм. Энэ цэгээс эхлээд бид Бурханд итгэх замналаа албан ёсоор эхэлж, хүний амьдралын хөшгийг албан ёсоор нээж, амьдралын зөв замд хөл тавьдаг. Өөрөөр хэлбэл, энэ үед бид Бурхан хүнтэй хамт амьдардаг зөв замд буюу хэвийн хүмүүсийн явдаг замд хөл тавьдаг. Бурханы өмнө зогсож, Түүнд үйлчилдэг нэгэн—сүмд тахилчийн өмсгөл өмсөж, Бурханы эрхэм чанар, эрх мэдэл, сүр жавхланг эзэмшдэг нэгний хувьд—Би бүх хүнд дараах тунхаглалыг тусгайлан гаргаж байна: Бурханы алдар суут төрх бол Миний алдар суу, Бурханы удирдлагын төлөвлөгөө бол Миний цөм. Махбодод гаргасан өчүүхэн зүтгэлийн минь ачаар Бурхан Өөрийн алдрын нэг жаахан хэсгийг эдлэг гэсэндээ Би, дараа ертөнцөд зуу дахин ихийг олж авахаар бус, энэ ертөнцөд Бурханы хүслийг биелүүлэхээр л эрэлхийлдэг. Энэ бол Миний цорын ганц хүсэл. Миний бодлоор, энэ Миний цорын ганц сүнслэг дэмжлэг юм. Махбодод амьдардаг, сэтгэл хөдлөлөөр дүүрэн нэгний “эцсийн үг” ийм байх ёстой гэж Би бодож байна. Энэ бол өнөөдөр Миний хөл дор байгаа зам. Миний бодлоор, энэ үзэл бодол бол махбод дахь эцсийн үг минь бөгөөд хүмүүс Миний талаар аливаа үзэл, өөр бодолгүй байгаа гэж найдъя. Хэдийгээр Би үүнд бүхнээ зориулсан ч тэнгэр дэх Бурханы хүслийг биелүүлж бас л чадаагүй байгаа. Би хэмжээлшгүй гунигтай байна. Махбодын гол чанар яагаад ийм байдаг юм бэ? Иймээс урьд нь Өөрийн хийсэн зүйлс, мөн Надад хийсэн Бурханы байлдан дагуулалтын ажлын үр дүнд л Би хүн төрөлхтний гол чанарын талаар илүү гүн гүнзгий ойлголттой болсон. Үүний дараа л Би, Бурханы хүслийг л биелүүлэхээр эрэлхийлэх, үүнд бүхнээ зориулах, мөс чанартаа ямар ч сэв суулгахгүй байх гэсэн хамгийн үндсэн стандартыг Өөртөө тавьсан. Бурханд үйлчилдэг бусад хүн өөрсдөөсөө юу шаарддагийг Би огт анхаардаггүй. Товчхондоо Би Бурханы хүслийг биелүүлэхээр сэтгэл шулуудсан. Бурханы өмнө үйлчилдэг бүтээлүүдийнх нь нэг, Бурханы аварч, хайрласан, Бурханы цохилтыг амссан нэгний хувиар өчих өчил минь энэ. Энэ бол Бурханы харж, хамгаалж, хайрлаж, ихээхэн ашигласан хүний өчил юм. Одоогоос эхлээд Би Бурханы даалгасан чухал даалгаврыг биелүүлэх хүртлээ энэ замаар үргэлжлүүлэн явна. Гэвч Миний бодлоор замын төгсгөл айсуй, учир нь Бурханы ажил дууссан бөгөөд хүмүүс өнөөдрийг л хүртэл хийж чадах бүхнээ хийсэн билээ.

Эх газрын Хятад энэхүү сэргэлтийн урсгалд орсноор Ариун Сүнсний ажилд төвлөрсөн орон нутгийн чуулганууд аажмаар бий боллоо. Энэ цаг үеэс төрөн

гарсан чуулганууд нуран унасан эзэн хааны гэр бүл дэх Бурханы цөм болсон учраас Бурхан орон нутгийн эдгээр чуулганд зогсолтгүй ажилласан юм. Бурхан ийм гэр бүлд орон нутгийн чуулгануудыг байгуулахдаа магнай тэнэгэр байсан гэдгийг хэлэх нь илүүц юм—Бурханы аз жаргалыг үгээр илэрхийлэх аргагүй байсан билээ. Эх газрын Хятадад орон нутгийн чуулгануудыг байгуулж, энэхүү сайхан мэдээг дэлхий даяар буй орон нутгийн бусад чуулганы ах эгч нарт түгээсний дараа Бурхан маш их догдолж байлаа—энэ нь эх газрын Хятадад Бурханы хийхээр зорьсон ажлын эхний алхам байсан юм. Үүнийг жүжгийн эхний үзэгдэл байсан гэж хэлж болно. Ямар ч хүн, ямар ч зүйл халдашгүй чөтгөрүүдийн ийм цайзад ажлынхаа эхний алхмыг эхлүүлэх чадвар нь Бурханы агуу хүч чадал бус уу? Энэ ажлыг сэргээхийн төлөө тоо томшгүй олон ах эгч тарчилж, диаволын зандалчны хутган дор үхсэн нь тодорхой. Үүнийг одоо сөхөхөд сэтгэл өвдөж, уур хүрч байгаа ч ерөнхийдөө зовлонт өдрүүд ард хоцорлоо. Өнөөдөр Би Бурханы төлөө ажиллаж, өдий хүртэл явж чадсан нь гагцхүү Бурханы үлэмж их хүч чадлын ач юм. Бурханы зовоож тарчлаахаар сонгосон хүмүүсийг Би асар их биширдэг; тэд Бурханы хүслийг биелүүлж, Бурханы төлөө өөрсдийгөө золослож чадсан. Үнэндээ Бурханы нигүүлсэл, өршөөл байгаагүй бол Би аль эрт намаг балчигт уначихсан байх байлаа. Бурханд талархъя! Бурханыг амраахын тулд Би бүх алдар сууг Бурханд өгөхийг хүсэж байна. “Та ийм байр суурьтай юм чинь үхэх ёсгүй. Бурхан үхлийг дурдах үед Та яагаад баярладаг юм бэ?” гэж зарим хүн Надаас асуудаг. Би шулуухан хариулахын оронд зүгээр л жаахан инээмсэглээд, “Энэ бол Миний эрэлхийлэх ёстой, заавал дагах ёстой зам” гэж хэлдэг. Хариултад минь хүмүүс будилдаг юм. Тэд Надад бага зэрэг эргэлзэж, ердөө л мэл гайхан өөдөөс ширтэж чаддаг. Гэхдээ энэ бол Миний сонгосон зам, бас Бурханы өмнө гаргасан шийдвэр учраас бэрхшээл хэчнээн их байлаа ч Би урагш зүтгэсээр байх ёстой гэж боддог. Миний бодлоор бол, энэ нь Бурханд үйлчилдэг хүмүүсийн баримтлах ёстой амлалт—тэд хэлснээсээ өчүүхэн ч буцах ёсгүй. Энэ нь бас Бурханд итгэдэг хүний ойлгох учиртай, аль эрт, Хуулийн эрин үед гарсан дүрэм, журам мөн. Би туршлагадаа Бурханы талаар нэг их мэддэггүй, үнэхээр туулсан зүйл минь шалихгүй, яриад байх ухаалаг ойлголтгүй байх хэмжээнд бүр дурдахын ч хэрэггүй боловч Бурханы үгийг баримтлах ёстой бөгөөд зөрчиж болохгүй. Яг үнэндээ Миний бодит туршлага ялихгүй ч Бурхан Надад гэрчлэл хийж, Би гэх хүнд хүмүүс үргэлж сохроор итгэдэг хойно яах ч билээ? Гэхдээ хүмүүс Бурханыг хайрлах тухай үзэл бодлоо засаж залруулна гэж Би найдсаар л байна. Би гэх хүн юу ч биш; учир нь Би ч бас Бурханд итгэх замыг эрэлхийлдэг бөгөөд Миний алхдаг зам мөн л Бурханд итгэх өнөөх зам юм. Хүн сайн байж болох ч шүтлэг мөргөлийн бай болох ёсгүй—тэд зөвхөн дагах үлгэр жишээ л болж болно. Өрөөл бусад юу хийдгийг Би тоодоггүй, гэхдээ Би ч бас Бурханд алдар суу өгдөг гэдгээ хүмүүст тунхагладаг; Би Сүнсний алдар сууг махбодод өгдөггүй. Энэ талаарх сэтгэлийг минь хүн бүр ойлгож чадна гэж найдъя. Би хариуцлагаасаа булталж байгаа юм биш, зүгээр л бүх түүх энэ. Энэ нь тов тодорхой байх ёстой, тиймээс дахин энэ талаар ярихгүй.

Өнөөдөр Би Бурханы өмнө гэгээрсэн. Газар дээрх Бурханы ажил нь авралын ажил юм. Үүнд өөр юу ч холилдоогүй байдаг. Зарим хүн өөр бодолтой байж болох ч Ариун Сүнс өөр ямар ч ажил бус, авралын ажлын нэг үе шатыг л хийж байгааг Би үргэлж мэдэрч ирсэн. Энэ тодорхой байх учиртай. Эх газрын Хятад дахь Ариун Сүнсний ажил одоо л тодорхой боллоо. Тэгвэл чөтгөрүүд тархсан ийм газарт Бурхан яагаад бүх замыг нээж, ажиллахыг хүсдэг юм бэ? Хамгийн гол нь Бурхан авралын ажил хийж байгааг энэ нь харуулдаг. Илүү нарийндаа бол энэ нь гол төлөв байлдан дагуулалтын ажил юм. Анхнаасаа Есүсийн нэр дуудагдаж ирсэн. (Зарим нь үүнийг мэдрээгүй байх, гэхдээ энэ нь Ариун Сүнсний ажлын нэг алхам байсан гэдгийг хэлье.) Нигүүлслийн эрин үеийн Есүсээс хагацахын төлөө ингэсэн тул хэсэг хүнийг урьдчилан сонгоод, дараа нь тэр сонголтыг хумьсан. Үүний дараа эх газрын Хятадад Витнесс Ли дуудагдсан нь эх газрын Хятад дахь Ариун Сүнсний сэргэлтийн ажлын хоёр дахь хэсэг байсан юм. Ариун Сүнс хүмүүсийг сонгож эхэлсэн ажлын эхний алхам энэ байсан бөгөөд эхлээд хүмүүсийг цуглуулаад, тэднийг хариулах хоньчныг хүлээсэн; тэр үйлчлэлийг хийхэд “Витнесс Ли” гэх нэрийг ашигласан юм. “Хүчит” гэх нэрийг гэрчлэхэд Бурхан ажлаа биечлэн хийсэн бөгөөд үүний өмнө бэлтгэл үе шат байсан. Иймээс тэр нь зөв байсан уу, буруу байсан уу гэдэг нь хамаагүй, энэ бол Бурханы төлөвлөгөөн дэх гол сэдэв биш юм. “Хүчит” гэх нэрийг гэрчилсний дараа Бурхан Өөрийн ажлыг албан ёсоор биечлэн хийж эхэлсэн бөгөөд үүний дараа махбод дахь Бурханы хувиар үйл хэрэг нь албан ёсоор эхэлсэн. “Хүчит Эзэн” гэх нэрээр Тэр тэрслүү, дуулгаваргүй байсан бүх хүнийг хяналтад авсан. Хүмүүс хорин гурав, хорин дөрөв хүрэхээрээ насанд хүрэгчид шиг болж эхэлдгийн адилаар тэд хүний төрхтэй болж эхэлсэн юм; өөрөөр хэлбэл, хүмүүс хэвийн хүний амьдралтай болж дөнгөж эхлээд байлаа. Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтаар Бурханы ажил, бурханлаг ажил хийх үе шатанд аяндаа шилжсэн юм. Ажлын энэ алхам л Бурханы маш их ажлын цөмийг бүрдүүлдэг бөгөөд Бурханы ажил дахь үндсэн алхам гэж хэлж болох юм. Хүмүүс өөрсдийгөө мэдэж, үзэн яддаг. Тэд өөрсдийгөө хараж чаддаг болж, баяртайяа амиа өгөх болж, Бурханы хайр татам байдлыг үл ялиг мэдрэхүйц цэгт хүрсэн бөгөөд энэ суурин дээр хүний оршин тогтнолын жинхэнэ утга учрыг мэдэж авч, улмаар Бурханы хүслийг биелүүлдэг. Эх газрын Хятад дахь Бурханы ажил дуусаж байна. Бурхан энэ бузар булай газарт хэдэн жилийн турш бэлтгэлээ явуулж ирсэн атал хүмүүс одоо хүрсэн цэгтээ урьд нь хэзээ ч хүрч байгаагүй, тэгэхээр өнөөдөр л Бурхан ажлаа албан ёсоор эхэлдэг гэсэн үг юм. Үүнийг илүү нарийн ширийнээр дэлгэрүүлж, тодруулах хэрэггүй. Энэ ажил шууд Бурханы бурханлаг чанараар хийгддэг гэж хэлэх нь бүхэлдээ зөв, гэхдээ энэ нь хүнээр дамжин хийгддэг. Үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Газар дээрх Бурханы агуу хүч чадлаас үүдэн, садар самуун энэ газар нутгийн хүмүүс дээрх ажил нь өнөөгийн энэ хэмжээнд хүрч чадсан нь лавтай. Энэ ажлын үр өгөөжийг хаана ч аваачин, хүмүүсийг үнэмшүүлж болно. Үүнийг хэн ч хөнгөн хуумгай шүүж, үгүйсгэж зүрхлэхгүй.

ЗАМ… 2

Эх газрын Хятад дахь Бурханы ажлын эрэмбэ дараа, алхам, арга барилын талаар манай ах эгч нар бага зэрэг ойлголттой байж болох ч эдгээрийг эргэн харж, товч дүгнэлт хийх нь зохистой гэж Би бодож байна. Би энэ боломжийг ашиглаад зүрх сэтгэлдээ байгаа зүйлийг л хэлнэ, харин энэ ажлаас давсан асуудлын талаар ярихгүй. Ах эгч нар Миний сэтгэл санааг ойлгож чадна гэж найдъя, бас Миний үгийг уншсан бүх хүнээс, өчүүхэн биеийн хэмжээ, хангалтгүй амийн туршлага, Бурханы өмнө нүүр бардам байх чадваргүй байдлыг минь ойлгож, уучлаарай гэж даруухнаар хүсье. Гэхдээ л Миний бодлоор эдгээр нь объектив шалтгаанаас цаашгүй. Товчхондоо гэвэл, юу ч боллоо гэсэн Бурханы өмнө нөхөрлөл хийхэд маань ямар ч хүн, үйл явдал, эд зүйл саад болж чадахгүй бөгөөд Бурханы өмнө илүү шаргуу ажиллахад ах эгч нар Надтай хүч хавсарна гэж найдаж байна. Би дараах залбирлыг өргөхийг хүсэж байна: “Өө Бурхан минь! Биднийг өршөөгөөч, тэгснээр ах эгч бид нэгдсэн туйлын зорилгынхоо ноёрхол дор хамтдаа тэмцэж, үхэн үхтлээ Танд итгэлтэй байж, хэзээ ч харамсахгүй байж чадна!”. Эдгээр үг бол Бурханы өмнөх Миний шийдвэр, мөн түүнчлэн Бурханы ашигладаг бие махбодтой хүн Миний Өөрийн уриа гэж хэлж болох юм. Би эдгээр үгийг дэргэдэх ах эгч нартаа олон удаа нөхөрлөж, хамт байгаа хүмүүстээ захиас болгон өгсөн. Хүмүүс эдгээрийг юу гэж боддогийг мэдэхгүй, гэхдээ ямартай ч эдгээр үг субьектив зүтгэлийн талаас гадна мөн объектив онолын талыг агуулдаг гэдэгт Би итгэдэг. Үүнээс үүдэн зарим хүн тодорхой нэг санал бодолтой байж болох бөгөөд чи эдгээр үгийг өөрийн уриа болгож, Бурханыг хайрлах эрмэлзэл чинь хэр ихсэхийг харсан нь дээр. Зарим хүн эдгээр үгийг уншаад тодорхой нэг үзэлтэй болж, “Бурханыг үхэн үхтлээ хайрлах асар их эрмэлзлийг хүмүүст өгөхийн тулд ийм өдөр тутмын, хэвийн юм хэлж яаж болдог юм бэ? Бас энэ нь бидний хэлэлцэж буй ‘Зам’ гэдэг сэдэвтэй ямар ч хамаагүй” гэж бодно. Эдгээр үг гойд сэтгэл татам биш байж болохыг Би хүлээн зөвшөөрч байна, гэхдээ эдгээр нь хүмүүсийг зөв зам руу хөтөлж, Бурханд итгэх замдаа зүрх алдаж, эргэж буцахгүйгээр бүх төрлийн шалгалт туулах боломж олгож чадна гэж Би үргэлж бодсоор ирсэн. Ийм учраас Би эдгээрийг үргэлж Өөрийн уриа хэмээн үздэг юм. Хүмүүс ч бас эдгээрийг хянамгай бодож тунгаана гэж Би найддаг. Гэхдээ Би хүн болгоноор Өөрийн үзэл бодлыг албадан хүлээн зөвшөөрүүлэх гэж зориогүй—энэ зүгээр л санал юм. Бусад хүн Намайг юу ч гэж бодлоо гэсэн, Бурхан бидний нэг бүрийн дотоод хөдөлгөгч хүчийг ойлгодог гэж Би боддог. Бурхан бидний нэг бүрд тогтмол ажиллаж байгаа бөгөөд Түүний ажил эцэж цуцашгүй юм. Бид бүгд агуу улаан лууны улс оронд төрсөн учраас Бурхан бидэн дээр ийм маягаар ажилладаг. Агуу улаан лууны улс оронд төрсөн хүмүүс Ариун Сүнсний энэ ажлыг олж авах хувьтай. Тэдний нэг болохын хувьд Би Бурханы сэтгэл булаам, хүндлүүштэй, хайр татам байдлыг асар их мэдэрдэг. Энэ бол Бурхан биднийг халамжилж байгаа хэрэг юм. Ийм хоцрогдмол, хуучинсаг, феодалын, мухар сүсэгтэй, гажуудсан,

ажилчин ангийн эзэнт гүрэн Бурханаас ийм ажил олж авч чадна гэдэг нь сүүлчийн эрин үе дэх энэ бүлэг хүмүүс бид хэчнээн их ерөөгдсөнийг харуулдаг. Сүнслэг нүд нь нээгдэн энэ ажлыг хардаг бүх ах эгч үүнээс үүдэн баярын нулимс унагана гэдэгт Би итгэдэг. Тэр үед чи баяр хөөртэйгөөр бүжин Бурханд өөрийгөө илэрхийлэх бус уу? Зүрх сэтгэл дэх дуугаа чи Бурханд өргөн барихгүй гэж үү? Тэр үед чи Бурханд шийдвэрээ харуулж, Бурханы өмнө өөр нэгэн төлөвлөгөө гаргах биш үү? Бурханд итгэдэг хэвийн хүмүүс энэ бүгдийг хийх учиртай гэж Би бодож байна. Хүн болохын хувьд бид дор бүрнээ Бурханы өмнө нэг төрлийн илэрхийлэлтэй байх ёстой гэдэгт Би итгэдэг. Сэтгэл хөдөлтэй хүний хийх ёстой зүйл энэ. Бидний дундах хүн бүрийн хэв чанар, төрсөн газрыг ганц харахад л Бурхан бидний дунд ирэхийн тулд яг хэчнээн их доромжлол туулсан нь харагддаг. Бид дотроо Бурханы талаар багахан мэдлэгтэй байж болох ч Бурхан маш агуу, дээдийн дээд, маш хүндтэй гэж бидний мэддэг зүйлс хүн төрөлхтний дундах Бурханы зовлон хэчнээн их байсныг онцлоход хангалттай байдаг. Гэвч Миний эдгээр үг бас л тодорхойгүй бөгөөд хүмүүс эдгээрийг бичиг үсэг, хоосон сургаал гэж үзэхээс өөр аргагүй, учир нь бидний дунд байгаа хүмүүс дэндүү хөшүүн, маанаг. Иймээс үүнийг хүлээн зөвшөөрөх ах эгч нарт энэ асуудлыг тайлбарлахад илүү их хүчин чармайлт гаргах нь Миний цорын ганц сонголт бөгөөд ингэснээр Бурханы Сүнс бидний сүнсийг хөдөлгөж чадна. Бурхан бидний сүнслэг нүдийг нээж, тэгснээр бид Бурханы төлсөн төлөөс, гаргасан зүтгэл, бидний төлөө зарцуулсан эрч хүчийг харах болтугай.

Эх газрын Хятадад Бурханы Сүнсийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийн нэг болохын хувьд Би хэв чанар яг хэр дутуу дулимаг болохыг сайн мэднэ. (Ах эгч нар маань үүнээс болж сөрөг болохгүй байх гэж найдъя—бодит нөхцөл байдал ийм байгаа юм.) Бидэнд юу байгаа, бид юу болох нь бүгд маш хоцрогдмол гэдгийг Би бодит амьдралдаа тодорхой харсан. Өргөн хүрээнд гэвэл, амьдралдаа болон Бурхантай харилцах харилцаандаа бидний биеэ авч явдаг байдал, нарийн хүрээнд гэвэл бидний санаа, бодол болгон ийм байдаг. Эдгээр нь бүгд бодитоор оршдог зүйлс бөгөөд үг яриа, дүр эсгэлтээр нуун далдлахад хэцүү байдаг. Иймээс Намайг ингэж хэлэх үед хэвийн эрүүл ухаангүй л биш бол ихэнх хүн толгой дохин, хүлээн зөвшөөрч, үнэмшдэг: Тийм хүмүүс Миний эдгээр үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй. Энэ хүмүүсийг жинхэнэ араатан гэж улайм цайм хэлж байгаа минь хэт бүдүүлэг байж магадгүй. Учир нь агуу улаан лууны улс оронд тэд гахай нохой шиг адгийн дорд байдаг. Тэд хэв чанараар хамгийн дулимаг; мөн Бурханы өмнө очих үнэ цэнгүй. Миний үг дэндүү “эрээ цээргүй” байж магад. Миний дотор ажиллаж байгаа Бурханы Сүнсийг төлөөлөхдөө Би араатан адил ийм бузар бүтээлийг хараадаг, ах эгч нар маань үүнээс болж сул дорой болдоггүй гэж найдаж байна. Бидний дунд тийм хүн байхгүй байх боломжтой, гэхдээ үнэн ямар ч байлаа гэсэн тийм хүмүүст ингэж хандах ёстой гэдэгт Би итгэдэг. Чи юу гэж бодож байна вэ?

Агуу улаан лууны эзэнт гүрэн хэдэн мянган жил оршин тогтнож, энэ хугацааныхаа туршид гажуудсан—мөн энэ бүх хугацаанд Бурханыг эсэргүүцсэн

учраас Бурханы хараал, уур хилэнтэй тулгарч, дараа нь Бурханы гэсгээлт ирсэн юм. Бурханаар хараагдсан энэ улс орон арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлд тасралтгүй өртөж ирсэн бөгөөд хоцрогдмол улс хэвээр байна. Иймээс бидний төрсөн энэ улсад ноёрхлыг цадиггүй эрэлхийлдэг элдэв янзын бузар чөтгөр дүүрэн байдаг—тэгэхээр тэд энд төрсөн хүмүүсийг буртагладаг гэсэн үг. Хүмүүсийн зуршил, зан заншил, санаа, үзэл баримтлал нь хоцрогдмол, хуучинсаг тул Бурханы талаар янз бүрийн үзэлтэй болж, өнөөг хүртэл үүнээсээ ангижирч чадаагүй л байна. Ялангуяа тэд Бурханы өмнө нэг янз байж, ар хударгаар нь өөр нэг янзаар аашилж, Сатаныг тахих явдлыг Бурханд үйлчилж байна гэж эндүүрдэг бөгөөд тэд хамгийн хоцрогдмол гэдэг нь эндээс харагддаг. Бурхан эх газрын Хятадад маш их ажил явуулж, маш олон үгээ хэлсэн боловч хүмүүс туйлын хөшүүн, хэнэггүй хэвээр байна. Тэд урьд нь хийдэг байсан ажлаа хийсээр байгаа бөгөөд Бурханы үгийн талаар ямар ч ойлголтгүй байдаг. Ямар ч ирээдүй, итгэл найдвар гэж үгүй хэмээн Бурханыг тунхаглах үед зуны халуунд амьд мэнд байсан чуулган тэр дороо хүйтэн өвөлд унасан. Хүмүүсийн жинхэнэ төрх ил болж, урьдын итгэл, хайр, хүч чадал нь бүгд ул мөргүй алга болсон. Тэгээд өнөөдөр тэдний нэг нь ч амин чанараа буцаан олж аваагүй. Аман дээрээ тэд Бурханд хайртай гэж хэлдэг, мөн зүрх сэтгэлдээ гомдоллож зүрхэлдэггүй боловч ямартай ч тэдэнд тийм хайр ер байдаггүй. Яагаад тэр вэ? Манай ах эгч нар энэ баримтыг хүлээн зөвшөөрөх байх. Бурхан биднийг гэгээрүүлж, улмаар бид бүгд Түүний хайр татам байдлыг мэдэж, Бурханаа зүрх сэтгэлийнхээ угаас хайрлаж, бид бүгдэд байдаг Бурханыг хайрлах хайрыг янз бүрийн байр сууринаасаа илэрхийлэх болтугай; Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг гуйвшгүй зүрх сэтгэлийг Бурхан бидэнд хайрлах болтугай—Би ингэж найддаг. Ингээд хэлсэн чинь, бас бузар булай энэ газар нутагт төрсөн ах эгч нараа бага зэрэг өрөвдөж, улмаар Миний сэтгэлд агуу улаан лууг гэх үзэн ядалт нэмэгдлээ. Агуу улаан луу Бурханыг хайрлахад маань саад болж, хэтийн ирээдүйн төлөөх шуналыг маань өдөөдөг. Тэгээд сөрөг байж, Бурханыг эсэргүүцэхэд биднийг уруу татдаг. Агуу улаан луу л, зүрх сэтгэлдээ Бурханы хайрыг хариулах чадваргүй болтол маань өнөөг хүртэл биднийг хуурч, завхруулж, сүйд хийсэн. Зүрх сэтгэлд маань эрмэлзэл бий ч бид өөрийн эрхгүй хүчин мөхөстдөг. Бид бүгд агуу улаан лууны хохирогчид. Ийм учраас Би агуу улаан лууг голдоо ортол үзэн яддаг бөгөөд үүнийг устгана гэхээс тэсэж яддаг. Гэхдээ дахиад бодохоор, ингэх нь ямар ч нэмэргүй, Бурханд төвөг л удна, тийм болохоор Би Бурханы хүслийг биелүүлэх—Бурханыг хайрлахаар сэтгэл шулуудсан гэх эдгээр үгэн дээр эргэн ирдэг. Энэ нь Миний явж буй зам, Бурханы бүтээлүүдийн нэг болох Миний алхах ёстой зам юм. Би амьдралаа ийнхүү өнгөрүүлэх ёстой. Энэ Миний чин зүрхний үг бөгөөд ах эгч нар эдгээр үгийг уншаад урам зориг авна гэж найдаж байна, тэгвэл Миний зүрх сэтгэл амар амгалан болж чадна. Учир нь Бурханы хүслийг биелүүлж, улмаар утга учиртай, гэрэлтэй, цог жавхаатай амьдралыг амьдран харуулах нь Миний зорилго. Ингэснээр би сэтгэл ханамж, тайтгарал

дүүрэн зүрх сэтгэлтэйгээр, харуусалгүй насан эцэслэж чадна. Чи тэгмээр байна уу? Чи тийм шийдвэртэй хүн мөн үү?

Бурхан “Зүүн Азийн өвчтөн” гэгч дээр ажиллаж чаддаг нь Түүний агуу хүч чадал юм. Энэ бол Бурханы даруу, нууцлаг байдал билээ. Бидэнд чиглэсэн хатуу үг, гэсгээлтийг нь үл харгалзан Бурханыг бид даруу байдлынх нь төлөө зүрх сэтгэлийнхээ угаас магтаж, үүнийх нь төлөө эцсээ хүртэл хайрлах ёстой. Хэдэн мянган жилийн турш Сатанд хүлээтэй байсан хүмүүс Сатаны нөлөөн дор амьдарсаар байгаа бөгөөд түүнээс зугтаагүй. Тэд гашуунаар тэмтчин, тэмцсээр ирсэн. Урьд нь тэд хүж шатааж, Сатанд мөргөж, Сатаныг шүтдэг байсан бөгөөд гэр бүл, дэлхий ертөнцийн ээдрээ, нийгмийн харилцаанд бат хүлээтэй байсан. Тэгээд тэдгээрээс ангижирч чадаагүй. Бие биеэ барьж иддэг ийм нийгэмд утга учиртай амьдралыг хүн хаанаас олж чадах юм бэ? Хүмүүсийн өгүүлдэг зүйл бол зовлонт амьдрал, харин азаар Бурхан энэ гэм зэмгүй хүмүүсийг аварч, бидний амийг Өөрийн халамж, хамгаалалтад оруулсан, ингэснээр амьдрал маань баяр баясгалантай болж, санаа зовнилоор дүүрэн байхаа больсон. Бид өнөөг хүртэл Бурханы нигүүлсэл дор амьдарч ирлээ. Энэ нь Бурханы ерөөл биш үү? Хүн Бурханд хэрээс хэтэрсэн шаардлага тавих ичгүүргүй зантай байж яаж болох юм бэ? Бурхан бидэнд тийм багыг өгсөн гэж үү? Чи одоо ч сэтгэл ханаагүй юу? Бурханы хайрыг хариулах цаг нь болсон гэж Би бодож байна. Бид Бурханд итгэх замыг дагадаг учраас багагүй хэмжээний доог тохуу, гүжирдлэг, хавчлага туулж болох ч энэ нь утга учиртай зүйл гэж Би итгэдэг. Энэ бол ичгүүртэй бус, алдар суутай зүйл бөгөөд юу ч боллоо гэсэн бидний эдэлдэг ерөөл олон. Тоймгүй олон удаа урам хугарах үед Бурханы үг тайтгарал авчирч, нэг л мэдэхэд уй гашуу баяр хөөрөөр солигдсон. Тоймгүй олон удаа, хэрэгтэй байх үед Бурхан ерөөл авчирч, Бурханы үг биднийг хангасан. Тоймгүй олон удаа өвдөхөд Бурханы үг амьдрал авчирч—бид аюулаас мултарч, аюулаас эсэн мэнд гарсан. Та нар энэ мэт маш олон зүйлийг өөрсдийн мэдэлгүй аль хэдийн эдэлсэн. Чи үүнээс алийг нь ч санахгүй байна уу?

ЗАМ… 3

Амьдралдаа Би Бурханд бие, сэтгэлээ бүхэлд нь өгөхдөө үргэлж баяртай байдаг. Тэр үед л мөс чанар минь сэвгүй, бага зэрэг амар амгалан байдаг. Амийг эрэлхийлдэг хүмүүс эхлээд Бурханд бүхий л зүрх сэтгэлээ өгөх ёстой; энэ бол урьдач нөхцөл юм. Ах эгч нар маань Надтай хамт Бурханд ингэж залбираач гэж хүсье: “Өө Бурхан минь! Тэнгэр дэх Таны Сүнс газар дээрх хүмүүст нигүүлсэл хайрлаж, тэгснээр Миний зүрх сэтгэл Тан руу бүрэн эргэн, Миний Сүнсийг Та хөдөлгөж, Би зүрх сэтгэл, Сүнсэндээ Таны хайр татам байдлыг харж, газар дээрх хүмүүс Таны гоо үзэсгэлэнг харахаар ерөөгдөх болтугай. Бурхан минь! Таны Сүнс дахин нэгэнтээ бидний сүнсийг хөдөлгөж, тэгснээр бидний хайр үүрд мөнхийн,

хувиршгүй байх болтугай!” Бид бүгдийн хувьд Бурхан эхлээд зүрх сэтгэлийг маань туршдаг—тэгээд биднийг сэтгэлээ уудалмагц сүнсийг маань хөдөлгөж эхэлдэг. Бурханы хайр татам, дээдийн дээд, агуу байдлыг бид сүнсээрээ л харж чадна. Энэ бол хүмүүс дэх Ариун Сүнсний зам юм. Чамд ийм амьдрал бий юу? Чи Ариун Сүнсний амьдралыг мэдэрсэн үү? Сүнсийг чинь Бурхан хөдөлгөсөн үү? Ариун Сүнс хүмүүс дээр хэрхэн ажилладгийг чи харсан уу? Чи бүхий л зүрх сэтгэлээ Бурханд өгсөн үү? Бурханд бүхий л зүрх сэтгэлээ өгсөн үедээ чи Ариун Сүнсний амьдралыг шууд мэдэрч чаддаг бөгөөд Түүний ажил чамд цаг үргэлж илчлэгдэнэ. Тэр үед чи Ариун Сүнсний ашигладаг хүн болно. Чи тийм хүн болохыг хүсэж байна уу? Миний санаж байгаагаар, Би анх удаа Ариун Сүнсээр хөдөлгөгдөн, Бурханд зүрх сэтгэлээ өгөх үедээ Бурханы өмнө унаж, “Өө Бурхан минь! Та нүдийг минь нээж, Таны авралыг мэдэх боломж олголоо. Би Танд зүрх сэтгэлээ бүхэлд нь өгмөөр байна, бас Таны хүсэл биелээсэй л гэж гуйя, Миний зүрх сэтгэл Таны өмнө сайшаал хүртээсэй л гэж хүсье, Би Таны хүслийг л дагамаар байна” гэж дуу алдсан. Тэр залбирлыг Би хэзээ ч мартахгүй; сэтгэл минь ихэд хөдөлж, Бурханы өмнө шаналант нулимс унагасан юм. Энэ нь аврагдсан хүний хувиар Бурханы өмнө хийсэн анхны бүтэлтэй залбирал, зүрх сэтгэлийн минь эхний хүсэл байлаа. Үүний дараа Ариун Сүнс Намайг үргэлж хөдөлгөдөг болсон. Чамд иймэрхүү туршлага байсан уу? Ариун Сүнс чам дээр яаж ажилласан бэ? Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг бүх хүнд ийм туршлага их бага хэмжээгээр байдаг гэж Би боддог—тэд зүгээр л мартчихдаг юм. Хэрвээ хүнд тийм туршлага байгаагүй гэж хэлбэл тэрээр хараахан аврагдаагүй, Сатаны эзэмшилд байсаар байгаа гэдгийг энэ нь нотолдог. Бид бүгдэд нийтлэг байдаг Ариун Сүнсний ажил бол Ариун Сүнсний зам бөгөөд энэ нь бас Бурханд итгэж, Бурханыг эрж хайдаг хүмүүсийн зам юм. Хүмүүс дээр Ариун Сүнсний хийдэг ажлын эхний алхам нь тэдний сүнсийг хөдөлгөх явдал, дараа нь тэд Бурханыг хайрлаж, амийг эрэлхийлж эхэлдэг бөгөөд энэ замаар алхдаг бүх хүн Ариун Сүнсний урсгалд байдаг. Эдгээр нь эх газрын Хятад дахь Бурханы ажлыг төдийгүй бүхий л орчлонг хөдөлгөгч хүч юм. Тэрээр хүн бүхэнд ийнхүү ажилладаг. Хэрвээ хүний сэтгэл хэзээ ч хөдөлж байгаагүй бол сэргэлтийн урсгалын гадна байгааг энэ нь нотолдог. Бурхан бүх хүнийг хөдөлгөөсэй, тэгээд нарны доорх хүн болгоны сэтгэл хөдөлж, энэ замаар алхаасай гэж Би зүрх сэтгэлдээ Бурханд тасралтгүй залбирдаг. Энэ нь Бурханд тавих ялихгүй хүсэлтээс цаашгүй байж болох ч Бурхан үүнийг хийнэ гэдэгт Би итгэдэг. Тэнгэр дэх Бурханы Сүнсийг амраахын тулд Бурханы хүсэл биелээсэй, Бурханы ажил удалгүй дуусаасай хэмээн бүх ах эгч маань үүний төлөө залбирна гэж Би найдаж байна. Энэ Миний өчүүхэн найдлага билээ.

Бурхан чөтгөрүүдийн нэг цайзад ажлаа өрнүүлж чадсан тул орчлон ертөнц даяарх бусад тоо томшгүй олон газарт ч өрнүүлж чадах нь лавтай гэж Би боддог. “Эцсээ хүртэл дагадаг хүн аврагдана” гэж хэлсэн байдагчлан сүүлчийн эрин үеийн бид Бурханы алдрын өдрийг үзэх нь гарцаагүй. Бурханы ажлын энэ үе шатанд

Бурханыг хэн ч орлож чадахгүй—Бурхан Өөрөө л энэ ажлыг хийж чадна, учир нь ажлын энэ үе шат нь ер бусын, мөн байлдан дагуулалтын ажлын үе шат бөгөөд хүмүүс бусад хүнийг байлдан дагуулж чаддаггүй. Бурхан Өөрийн биеэр үг хэлж, Өөрийн гараар үйлдэх үед л хүмүүс байлдан дагуулагддаг. Бурхан бүх орчлон ертөнцийн дундаас агуу улаан лууны улс орныг туршилтын газар болгон ашигладаг бөгөөд дараа нь орчлон ертөнц даяар энэ ажлыг эхлүүлнэ. Тийнхүү орчлон даяар бүр ч агуу ажил явуулж, орчлон ертөнцийн бүх хүн Бурханы байлдан дагуулалтын ажлыг хүлээн авна. Шашин, урсгал бүрийн хүмүүс ажлын энэ үе шатыг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ бол явах ёстой зам—хэн ч үүнээс зайлсхийж чадахгүй. Бурханы даалгасан энэ зүйлийг чи хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна уу? Ариун Сүнсний даалгаврыг хүлээн авна гэдэг алдар суутай зүйл гэдгийг Би үргэлж мэдэрдэг байсан. Минийхээр бол, энэ нь хүн төрөлхтөнд Бурханы өгдөг хамгийн агуу даалгавар юм. Ах эгч нар маань Надтай хамт шаргуу ажиллаж, энэ даалгаврыг Бурханаас хүлээн авна гэж Би найдаж байна, ингэснээр Бурхан бүх орчлон ертөнцийн дээр, доор алдрыг олж авч, бидний амьдрал хий дэмий өнгөрөхгүй. Бид Бурханы төлөө ямар нэг юм хийх ёстой, эсвэл тангараг өргөх учиртай. Хэрэв хүмүүс Бурханд итгэхдээ эрэлхийлэх зорилгогүй байдаг бол амьдрал нь талаар болох ба үхэх цаг нь ирэхэд тэд гагцхүү хөх тэнгэр, тоост газрыг л харна. Энэ утга учиртай амьдрал мөн үү? Чи амьд ахуйдаа Бурханы шаардлагыг биелүүлж чадвал сайхан биш үү? Яагаад дандаа өөртөө ингэж төвөг уддаг юм бэ, яагаад үргэлж ингэж уруу царайлдаг юм бэ? Чи ингэж авирлаад Бурханаас юм олж авсан уу? Бас Бурхан чамаас ямар нэг юм олж авч чадах уу? Бурханд өргөсөн тангарагт минь Миний зүрх сэтгэлийн амлалт л байсан; Би Бурханыг үгээрээ хуурах гээгүй. Би тийм зүйл хэзээ ч хийхгүй—тэнгэр дэх Сүнсэнд нь тайтгарал авчрахын тулд зүрх сэтгэлээсээ хайрладаг Бурханаа тайтгаруулахыг л хүсдэг. Зүрх сэтгэл үнэ цэнтэй байж болох ч хайр илүү эрхэм нандин юм. Би Өөрийн зүрх сэтгэл дэх хамгийн эрхэм нандин хайрыг Бурханд өгнө, тэгснээр Бурхан Надад байгаа хамгийн үзэсгэлэнтэй сайхан зүйлийг эдэлж, Миний өргөн барьдаг хайранд сэтгэл ханаж магад. Чи Бурханд хайраа өгч, эдлүүлэхэд бэлэн үү? Үүнийг чи оршин тогтнолынхоо хөрөнгө болгоход бэлэн үү? Миний туршлагаас харахад Бурханд хайраа хэдий чинээ өгнө, амьдралаас төдий чинээ баяр баяслыг мэдэрдэг; түүнчлэн хүч чадалд минь хязгаар гэж үгүй бөгөөд бүхий л бие, сэтгэлээ баяртайяа өргөж, Бурханыг хайрлаж ханахгүй мэт мэдрэмж байнга төрдөг. Тэгэхээр чиний хайр ялихгүй хайр уу, аль эсвэл хязгааргүй, энгүй их хайр уу? Хэрвээ чи үнэхээр Бурханыг хайрлахыг хүсдэг бол Бурханд буцааж өгөх илүү их хайр чамд үргэлж байх болно—тэр тохиолдолд Бурханыг хайрлах замд чинь ямар хүн, ямар зүйл саад болж чадах билээ?

Бурхан хүн бүрийн хайрыг нандигнадаг. Бурханыг хайрладаг бүх хүнд Бурханы ерөөл хоёр дахин үрждэг, учир нь хүний хайрыг олох тун хэцүү бөгөөд хүний хайр бараг үл анзаарагдам, өчүүхэн бага байдаг. Орчлон ертөнц даяар Бурхан, Өөрийг

нь эргүүлэн хайрлаач хэмээн хүмүүсээс гуйж үзсэн ч өнөөг хүртэл эрин үеүдийн туршид ердөө цөөн хэдэн хүн л Бурханд эргүүлээд жинхэнэ хайр өгсөн билээ. Миний санаж байгаагаар, Петр тэдний нэг байсан ч Есүс түүнийг биечлэн замчилсан бөгөөд тэрээр үхэх үедээ л Бурханд бүрэн хайраа өгөөд, дараа нь насан эцэслэсэн юм. Иймээс эдгээр аймшигт нөхцөл байдалд Бурхан орчлон ертөнц дэх ажлынхаа цар хүрээг хумьж, агуу улаан лууны улс орныг үзүүлэнгийн бүс болгон ашиглаж, ажлаа илүү үр өгөөжтэй, гэрчлэлээ илүү ашиг тустай болгохын тулд бүх эрч хүч, хичээл зүтгэлээ нэг газарт төвлөрүүлсэн юм. Бурхан энэ хоёр нөхцөл дор бүхий л орчлон ертөнцийн ажлаа хамгийн муу хэв чанартай, эх газрын Хятад дахь энэ хүмүүст шилжүүлж, хайрын байлдан дагуулалтын ажлаа эхэлсэн. Тэднээр бүгдээр нь хайрлуулсныхаа дараа Бурхан ажлынхаа дараагийн алхмыг хэрэгжүүлнэ, энэ нь Бурханы төлөвлөгөө юм. Иймээс Бурханы ажил хамгийн их үр нөлөө үзүүлдэг. Бурханы ажлын цар хүрээнд цөм ч бий, хязгаарлалт ч бий. Бурхан бидний өдрийг авчрахын тулд бидэн дээр ажлаа явуулж байхдаа хэр их төлөөс төлж, хэдий их хүчин зүтгэл гаргасан нь тодорхой. Энэ бол бидний ерөөл. Тиймээс өрнөдийнхөн биднийг сайхан газарт төрсөн гэж атаархаж байхад, харин бид бүгд өөрсдийгөө дорд, дорой гэж үздэг нь хүмүүсийн үзлийг нураадаг. Бурхан биднийг өргөж байгаа нь энэ биш үү? Үргэлж дэвслүүлж ирсэн, агуу улаан лууны үр удмыг өрнөдийнхөн хүндэлж байгаа нь үнэхээр бидний ерөөл юм. Би энэ талаар бодохоор Бурханы сайхан сэтгэл, эрхэм, ойр дотно байдлаас болж сэтгэл хөдөлдөг. Бурханы хийдэг бүх зүйл хүний үзэлтэй нийцдэггүйг энэ нь харуулдаг. Хэдийгээр энэ бүх хүн хараагдсан ч Бурхан хуулийн хязгаарлалтад боогддоггүй бөгөөд газар дэлхийн энэ хэсэгт ажлынхаа төвийг албаар шилжүүлсэн юм. Иймээс Би хөөрөн баясаж, хэмжээлшгүй аз жаргалтай байдаг. Яг л израильчуудын дундах ахлах тахилчид шиг ажилд тэргүүлэх үүрэг хүлээдэг нэгний хувьд Би Сүнсний ажлыг шууд гүйцэтгэж, Бурханы Сүнсэнд шууд үйлчилж чаддаг; энэ бол Миний ерөөл. Хэн ийм юм төсөөлж зүрхлэх билээ? Гэтэл өнөөдөр энэ нь бидэн дээр гэнэтхэн ирлээ. Энэ үнэхээр тэмдэглүүштэй үлэмж их баяр баясал юм. Бурхан биднийг үргэлжлүүлэн ерөөж, өргөж, тэгснээр энэ өтөг баасан дунд амьдарч байгаа бид Бурханд сайн ашиглуулж, улмаар Бурханы хайрыг хариулна гэж Би найддаг.

Одоо Миний алхаж буй зам бол Бурханы хайрыг хариулах зам боловч энэ нь Бурханы хүсэл биш, бас Миний алхах учиртай зам биш гэсэн мэдрэмж цаг ямагт төрдөг. Бурханд сайн ашиглуулах нь Бурханы хүсэл, Ариун Сүнсний зам мөн. Би андуурсан байж магадгүй, гэхдээ үүнийг Өөрийн зам гэж боддог, учир нь Би, Бурханаар замчлуулахыг хүснэ, алхах учиртай замдаа яаравчлан хөл тавина, Бурханы хүслийг аль болох хуран биелүүлнэ хэмээн Бурханд аль эрт амласан билээ. Бусад нь юу ч гэж бодсон хамаагүй, Бурханы хүслийг дагах нь туйлын чухал гэдэгт Би итгэдэг. Миний амьдралд үүнээс чухал зүйл гэж үгүй, хэн ч энэ эрхийг минь хасаж чадахгүй. Энэ бол Миний хувийн үзэл бодол, зарим нь ойлгож чадахгүй байж болох ч үүнийг Би хэнд ч зөвтгөх албагүй гэж бодож байна. Би явах ёстой

замаараа явна—явах ёстой замаа танимагц түүгээрээ яваад, ухарч буцахгүй. Иймээс Би “Бурханы хүслийг биелүүлэхээр сэтгэл шулуудсан” гэх энэ үгэн дээр эргээд ирдэг. Ах эгч нар маань Намайг шүүмжлэхгүй гэдэгт итгэлтэй байна! Ерөнхийдөө, Миний хувийн бодлоор бол, бусад хүн юу дуртайгаа хэлж болох ч Бурханы хүслийг биелүүлэх нь хамгийн чухал зүйл бөгөөд үүн дээр Намайг юу ч хойш татах ёсгүй. Бурханы хүслийг биелүүлэхэд буруутна гэж хэзээ ч байхгүй! Бас энэ нь хувийн ашиг сонирхлынхоо төлөө явж байгаа хэрэг биш! Бурхан Миний сэтгэл доторхыг харсан гэдэгт Би итгэдэг! Тэгвэл чи үүнийг яаж ойлгох ёстой вэ? Өөрийгөө Бурханд өргөхөд чи бэлэн үү? Бурханаар ашиглуулахад бэлэн үү? Бурханы хүслийг дагана гэж чи амлах уу? Миний үг ах эгч нарт маань жаахан тус нэмэр болж чадна гэж Би найдаж байна. Миний мэдлэг ухаан тийм ч гүн гүнзгий биш боловч Би та нарт эдгээрийг мөн л хэлдэг, ингэснээр бид сэтгэлийн гүн дэх мэдрэмжээ өөр хоорондоо ямар ч саадгүй хуваалцаж, Бурхан бидний дунд үүрд байх болно. Энэ бол Миний чин сэтгэлийн үг. За! Өнөөдөр үнэн сэтгэлээсээ хэлэх ёстой үг минь ингээд дууслаа. Ах эгч нар маань шаргуу ажилласаар байна гэж Би найдаж байна, бас Бурханы Сүнс биднийг үргэлж харж хандана гэж найдъя!

ЗАМ… 4

Хүмүүс Бурханы хайр татам байдлыг олж мэдэж, өнөөгийн эрин үед Бурханыг хайрлах замыг эрж хайх чадвартай байж, өнөөдрийн хаанчлалын сургалтыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа нь бүгд Бурханы нигүүлсэл, мөн түүнчлэн Бурхан хүн төрөлхтнийг өргөж байгаа хэрэг юм. Би энэ талаар бодох бүрдээ Бурханы хайр татам байдлыг ихэд мэдэрдэг. Бурхан биднийг үнэхээр хайрладаг; тэгээгүй сэн бол Бурханы хайр татам байдлыг хэн олж мэдэж чадах билээ? Энэ бүх ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийдэг, хүмүүсийг Бурхан замчилж, залж чиглүүлдэг гэдгийг Би ингэж л олж хардаг. Үүний төлөө Бурханд талархъя, бас Надтай хамт Бурханыг магтаач гэж ах эгч нараасаа хүсье: “Дээдийн дээд Бурхан Өөрөө Танд бүх алдар суу байх болтугай! Таны алдар суу үржиж, Таны сонгож, олж авсан хүмүүс бидэнд илчлэгдэх болтугай”. Бурхан Намайг гэгээрүүлсэн: Бид олон мянган жилийн өмнө урьдчилан тогтоогдсон гэдгийг, мөн Бурхан биднийг эцсийн өдрүүдэд олж авахыг хүсэж, улмаар орчлон ертөнц болон бүх зүйл биднээр дамжуулан Бурханы алдар сууг бүхэлд нь харах боломжтой болсныг Бурхан Надад харуулсан юм. Тэгэхээр бид Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний биелэлт мөн; бид бол бүхий л орчлон ертөнц дэх Бурханы ажлын үлгэр дуурайл, загвар. Бурхан биднийг хэчнээн их хайрладаг гэдгийг, бидэн дээр хийдэг Бурханы ажил, Бурханы хэлдэг үг өнгөрсөн эрин үеүдийнхээс сая дахин илүү гэдгийг Би одоо л ухаарч байна. Бүр Израильд ч, Петрт ч Бурхан ийм их ажил биечлэн хийж, ийм олон үг хэлээгүй нь энэхүү бүлэг хүмүүс бид үнэхээр асар их ерөөгдсөн, өнгөрсөн үеийн

ариун хүмүүстэй зүйрлэшгүй их ерөөгдсөн гэдгийг харуулдаг. Тийм учраас Бурхан сүүлчийн эрин үеийн хүмүүс ерөөлтэй гэж үргэлж хэлж ирсэн. Бусад нь юу ч гэж хэллээ гэсэн Бурхан биднийг хамгийн их ерөөдөг гэдэгт Би итгэдэг. Бид Бурханы хайрласан ерөөлийг хүлээн авах ёстой; Бурханд гомдоллодог зарим хүн байж болох ч эдгээр ерөөл Бурханаас ирдэг юм бол бид үүнийг хүртвээс зохино гэдгийг энэ нь нотолдог. Бусад нь гомдоллож, бидэнд сэтгэл дундуур байлаа ч гэсэн Бурханы бидэнд өгсөн ерөөлийг өөр хэн ч өвлөж, биднээс булаан авч чадахгүй гэдэгт Би итгэсээр байна. Яагаад гэвэл, Бурханы ажил бидэн дээр явагддаг бөгөөд Бурхан бидэнтэй—өөр хэнтэй ч биш, бидэнтэй нүүр тулан үг хэлдэг—Бурхан Өөрийн хүссэнээр хийдэг. Харин хүмүүс үнэмшихгүй бол өөрсдөдөө л төвөг удаж байгаа хэрэг бус уу? Тэд тэгснээр өөрсдийгөө жигшүүртэй байдалд оруулдаг бус уу? Яагаад Би ингэж хэлдэг вэ? Яагаад гэвэл, Би үүнийг гүнээ ухаардаг. Жишээлбэл, Бурханы Надад хийдэг ажлыг авч үзье: Энэ ажлыг Би л хийж чадна—өөр хүн хийж чадах уу? Бурханаас энэ даалгаврыг хүлээн авах завшаан Надад тохиосон—өөр хэн нэгэн үүнийг дур сонирхлоороо хийж чадах уу? Гэхдээ ах эгч нар Миний зүрх сэтгэлийг ойлгоно гэж найдъя. Би эрх дархаараа онгирч байгаа юм биш, харин асуудлыг тайлбарлаж байна. Бүх алдар суу Бурханд байгаасай, нэг бүрийн маань зүрх сэтгэлийг Бурхан хараад, улмаар Бурханы өмнө бидний зүрх сэтгэл цэвэрлэгдээсэй гэж Би хүсдэг. Зүрх сэтгэлдээ Би Бурханаар бүрмөсөн авхуулж, тахилын ширээн дээр тахил болох цэвэр ариун онгон охин болж, түүнчлэн хурга шиг дуулгавартай байж, бүх хүн төрөлхтний дунд ариун сүнслэг биеэр гарч ирэхийг хүсдэг. Энэ бол Миний амлалт, Бурханы өмнө тавьсан тангараг билээ. Би үүнийг биелүүлж, үүгээр дамжуулан Бурханы хайрыг хариулахыг хүсдэг. Чи үүнийг хийхэд бэлэн байна уу? Миний энэ амлалт арай залуу ах эгч нарт эрч хүч нэмж, арай залуу хүмүүст найдвар авчирна гэж Би итгэж байна. Бурхан залуу хүмүүсийг нэн чухал гэж үздэг мэт санагддаг. Энэ Миний өрөөсгөл хандлага байж магадгүй, гэхдээ залуу хүмүүст хэтийн ирээдүй, найдвар байгааг Би үргэлж мэдэрдэг; Бурхан залуу хүмүүст нэмэлт ажил хийдэг мэт байдаг. Тэд хэрсүү ухаан, мэргэн ухаанаар дулимаг, бас дөнгөж төрсөн тугал шиг цовоо, бусгамтгай байж магад, гэхдээ тэдэнд өөрсдийн гэсэн давуу тал байгаа гэж Би боддог. Тэднээс залуу насны цайлган байдлыг харж болно, бас тэд шинэ зүйл хүлээн зөвшөөрөхдөө хурдан байдаг. Хэдийгээр залуу хүмүүс биеэ тоож, ширүүн, тавтиргүй байх хандлагатай байдаг ч энэ нь тэдний шинэ гэрэл хүлээн авах чадварт нөлөөлдөггүй, учир нь залуу хүмүүс хуучин, хоцрогдмол зүйлтэй зууралдах нь ховор. Тийм учраас Би залуу хүмүүсээс хязгааргүй их найдвар болон амин чанарыг олж хардаг; энэ шалтгаанаар тэднийг гэх энхрий зөөлөн сэтгэл Надад байдаг. Ахмад ах эгч нарт Би огт дургүйцдэггүй, гэхдээ тэднийг бас сонирхдоггүй—үүнд чин сэтгэлээсээ хүлцэл өчье. Миний хэлсэн үг хэрээс хэтэрсэн, аль эсвэл бодлогогүй байж магад, гэхдээ Би ярианыхаа хэв маягт тийм их анхаарал хандуулахад дэндүү залуу байгаа тул бодлогогүй байдлыг минь та бүгд уучилж чадна гэж найдъя. Гэхдээ үнэнийг хэлэхэд, ахмад ах эгч нар эцсийн эцэст чиг үүрэг

гүйцэтгэдэг—тэд ямар ч хэрэггүй байдаг юм биш. Яагаад гэвэл, тэд аливааг зохицуулах туршлагатай; юмыг зохицуулахдаа тууштай байж, тийм ч олон алдаа гаргадаггүй. Энэ нь тэдний давуу тал мөн биз дээ? Бүгдээрээ Бурханы өмнө ингэж хэлцгээе: “Өө Бурхан минь! Бид бүгд өөр өөр байр сууриндаа өөрсдийн гэсэн чиг үүргийг гүйцэтгэх болтугай, бас бид бүгд Таны хүслийг биелүүлэхийн төлөө чадах бүхнээ хийх болтугай!” Бурханы хүсэл ийм байх учиртай гэж Би итгэдэг!

Миний туршлагаар бол, энэ урсгалыг илэрхий эсэргүүцдэг, Бурханы Сүнсийг шууд эсэргүүцдэг хүмүүсийн олонх нь ахмад настай байдаг. Энэ хүмүүс шашны маш бат үзэлтэй байдаг; тэд алхам тутамдаа Бурханы үгийг хоцрогдсон юмтай харьцуулж, урьд нь хүлээн зөвшөөрөгдсөн юмыг Бурханы үгтэй нийцүүлэх гэж үздэг. Тэд утгагүй бус уу? Тийм хүмүүс Бурханы даалгасан ажлыг гүйцэтгэж чадах уу? Бурхан тийм хүмүүсийг ажилдаа ашиглаж чадах уу? Ажлынх нь аль ч өдөрт зориулсан арга барил Ариун Сүнсэнд байдаг; хэрэв хүмүүс хуучинсаг зүйлтэй зууралдвал нэг л өдөр түүхийн тавцангаас арчигдана. Бурхан ажлынхаа үе шат болгонд шинэ хүмүүсийг ашигладаг. Хоцрогдсон зүйлийг бусдад сургамжлах гэж хичээгсэд хүмүүст сүйрэл авчирдаг биш үү? Бас тэд Бурханы ажлыг саатуулж байгаа бус уу? Хэрэв тийм бол Бурханы ажил хэзээ дуусах юм бэ? Дөнгөж сая хэлсэн зүйлийн минь талаар зарим нэг үзэлтэй хүмүүс байж магад. Тэд үнэмшээгүй байж болох юм. Гэхдээ чамайг санаа зовоосой гэж Би хүсдэггүй: Удалгүй үүн шиг олон зүйл тохиолдох бөгөөд тэдгээрийг гагцхүү баримтаар тайлбарлаж болно. Хэдүүлээ зарим чухал хүн, нэр хүндтэй пастор, аль эсвэл Библи тайлбарлагч дээр айлчлан, энэ урсгалыг тэдэнд номлоё. Тэд эхэндээ үүнийг илт эсэргүүцэхгүй нь тодорхой—гэхдээ чамайг сорихын тулд Библи гаргаж ирнэ. Тэгээд чамаар Исаиагийн ном, Даниелийн номыг яриулж, тэр ч бүү хэл Илчлэлийн номыг тайлбарлуулна. Харин үүнийг нь ярьж чадахгүй бол чамайг голж, хуурамч Христ гэж нэрлээд, утгагүй зам түгээж байна гэцгээнэ. Нэг цагийн дараа тэд чамайг худлаа буруутгаж, амьсгал давхцахад хүргэнэ. Энэ нь илэрхий эсэргүүцэл биш үү? Гэхдээ энэ бол дөнгөж эхлэл. Тэд Бурханы ажлын дараагийн алхамд саад хийж чадахгүй бөгөөд төд удалгүй Ариун Сүнс үүнийг тэднээр хүчээр хүлээн зөвшөөрүүлнэ. Энэ бол мохошгүй чиг хандлага; хүний хийж чадахгүй зүйл, бүр хүмүүсийн төсөөлж ч чадахгүй зүйл юм. Орчлон даяар Бурханы ажил саадгүй түгнэ гэдэгт Би итгэдэг. Энэ нь Бурханы хүсэл бөгөөд хэн ч үүнийг зогсоож чадахгүй. Бурхан биднийг гэгээрүүлж, илүү их шинэ гэрэл хүлээн авах, мөн энэ асуудал дээрх Бурханы удирдлагад саад хийхгүй байх боломжийг бидэнд олгох болтугай. Бурхан биднийг өршөөж, улмаар бид бүгд Бурханы алдрын өдөр ирэхийг харж чадах болтугай. Бүхий л орчлон даяар Бурхан алдар сууд умбах тэр цаг үе нь бас бид Бурханы хамтаар алдар сууг олж авах үе байх болно. Түүнчлэн тэр нь бас Би хамт алхаж буй хүмүүсээсээ хагацах цаг байх юм шиг байна. Ах эгч нар минь Надтай хамт дуугаа өндөрсгөн Бурханаас гуйна гэж найдъя: Бурханы агуу ажил удалгүй дуусаж, улмаар бид амьд сэрүүн байхдаа Бурханы алдрын өдрийг үзэх болтугай.

Би энэ яваа насандаа Бурханы хүслийг биелүүлнэ гэж найдсаар байна, мөн Бурхан бидэн дээр ажлаа үргэлжлүүлэн хийж, хэзээ ч, ямар ч саад тотгор үүсэхгүй гэж найдаж байна. Энэ бол Миний мөнхийн эрмэлзэл. Бурхан үргэлж бидний дунд байж, Бурханы хайр бидний дунд гүүр болж, улмаар бидний хоорондох барилдлага улам эрхэм нандин болох болтугай. Хайр бидний дунд илүү их ойлголцол үүсгэж, хайр биднийг улам ойр дотно болгож, бидний хоорондох аливаа зай завсрыг арилгаж, бидний дундах хайр улам гүн гүнзгий, өргөн уудам, сайн сайхан болно гэж найдъя. Миний Бурханы хүсэл ийм байх учиртай гэж Би итгэж байна. Ах эгч нар маань Надтай илүү ойр дотно болж, хамтдаа өнгөрүүлэх ахархан өдөр хоногуудаа бүгд нандигнаж, эдгээр нь бидний сайхан дурсамж болно гэж найдъя.

Эх газрын Хятадад Бурханы ажлын алхам илүү олон байсан байж болох ч эдгээр нь ээдрээтэй биш. Бодоод үзэхэд, Бурханы ажлын алхам бүрд эрүүл ухаан байдаг; эдгээрийг дор бүрд нь Бурхан биечлэн явуулсан бөгөөд хүн болгон энэ ажилд дүр бүтээсэн юм. “Үйл явдал” бүр үнэхээр инээдэмтэй байдаг бөгөөд энэ хүмүүс ийм жүжиг тоглож, шалгалт бүрийн дунд жүжиглэлт нь дэндүү амьдралд ойр байж, Бурханы үзэг дор элдэв янзын хүн маш тод томруун, бүрэн дүрслэгдэж, дор бүрнээ ихийг илчилнэ гэж хэн төсөөлөх билээ? Гэвч ингэснээрээ Би, Бурхан ажлаараа дамжуулж хүмүүсээр тоглоом тохуу хийж байна гэж хэлэх гээгүй. Тэгэх нь ямар ч ухаангүй хэрэг болно; Бурханы ажилд зорилго гэж бий, Бурхан ямар ч утга учиргүй, үнэ цэнгүй зүйл хэзээ ч хийхгүй. Бурханы хийдэг бүх зүйл хүмүүсийг төгс болгож, олж авахын төлөө хийгддэг. Бурханы зүрх сэтгэл тэр чигтээ хүний сайн сайхны төлөө байдгийг Би үүнээс үнэхээр хардаг. Үүнийг Би жүжиг гэж нэрлэсэн байж болох ч энэ жүжгийг бодит амьдралаас сэдэвлэсэн гэж бас хэлж болох юм. Энэ жүжгийн ерөнхий найруулагч болох Бурханы хувьд л, энэ ажлыг дуусгахад Өөртэй нь хамтран ажиллах хүмүүс гэж байдаг. Гэвч нөгөө талаар Бурхан хүмүүсийг олж авах, тэднээр илүү их хайрлуулахдаа үүнийг ашигладаг. Бурханы хүсэл энэ биш үү? Тэгэхээр хэнд ч, ямар ч санаа зовнил байхгүй гэж Би найдаж байна. Бурханы хүслийг чи бүрэн мэддэггүй гэж үү? Би маш ихийг хэллээ—ах эгч нар үүнийг бүгдийг нь ойлгож, зүрх сэтгэлийг минь буруугаар ойлгоогүй байх гэж найдъя. Та нарыг бүгдийг нь Бурхан олж авна гэдэгт Би эргэлзэхгүй байна. Хүн бүр өөр өөр замаар алхдаг. Та нарын хөл доорх замыг Бурхан нээх болтугай, бас та нар Бурханд залбирч, “Өө Бурхан минь! Та намайг олж авч, тэгснээр сүнс минь Танд эргэн очоосой гэж хүсье” гэж хэлэх болтугай. Чи сүнснийхээ гүнд Бурханы удирдамжийг эрж хайхад бэлэн үү?

ЗАМ… 5

Урьд нь Ариун Сүнсний талаар хэн ч мэдээгүй, Ариун Сүнсний алхдаг замыг бүр ч мэдээгүй. Тийм учраас хүмүүс Бурханы өмнө өөрсдийгөө үргэлж инээдтэй байдалд оруулсаар ирсэн. Бурханд итгэдэг бараг бүх хүн Сүнсийг мэддэггүй, итгэл

нь будилж, төөрөлдсөн байдаг гэж хэлбэл зохино. Харваас хүмүүс Бурханыг ойлгодоггүй; аман дээрээ Бурханд итгэдэг гэцгээдэг ч ааш авирт нь үндэслэвэл, мөн чанартаа тэд Бурханд биш, өөрсдөдөө итгэдэг. Бодит туршлагаараа Би, Бурхан бие махбодтой болсон Бурханыг гэрчлэхийг харсан бөгөөд гаднаа хүмүүс Бурханы гэрчлэлийг албан хүчээр хүлээн зөвшөөрсөн мэт харагддаг. Бурханы Сүнс ямар ч алдаагүй гэдэгт тэд итгэдэг гэж л арай чүү хэлж болно. Гэхдээ хүмүүсийн итгэдэг зүйл нь энэ хүн биш, Бурханы Сүнс ч биш, өөрсдийнх нь мэдрэмж юм. Ингэснээрээ тэд зөвхөн өөрсдөдөө итгэж байгаа бус уу? Миний хэлж байгаа зүйл үнэн. Би хүмүүст нэр хаяг өгч байгаа юм биш, гэхдээ тодруулах ёстой нэг зүйл бий: Өдий хүртэл явж ирсэн хүмүүсийн хувьд тодорхой ойлголттой байна уу, будилсан байна уу гэдэг бүгд Ариун Сүнснээс шалтгаалдаг. Энэ нь хүмүүсийн хянадаг зүйл биш. Ариун Сүнс хүмүүсийг албан хүчээр итгүүлдэг талаар өмнө нь Миний дурдсан зүйлийн жишээ энэ юм; Ариун Сүнс ийм маягаар ажилладаг бөгөөд энэ нь Ариун Сүнсний явдаг зам юм. Мөн чанартаа хүмүүс хэнд ч итгэдэг байлаа гэсэн Ариун Сүнс албан хүчээр нэг төрлийн мэдрэмж өгч, тэднийг зүрх сэтгэлдээ Бурханд итгэдэг болгодог. Чи ийнхүү итгэдэг биш үү? Бурханд итгэх итгэл чинь хачин зүйл мэт санагддаггүй юу? Чи энэ урсгалаас гарч чадахгүй байгаагаа хачин жигтэй гэж боддоггүй юу? Чи энэ талаар бодоход ямар ч хичээл чармайлт гаргаагүй гэж үү? Бүх тэмдэг, гайхамшгаас хамгийн агуу нь энэ бус уу? Зугтаах сэдэл чамд олон удаа төрсөн ч чиний татагддаг, явмааргүй санагдуулдаг хүчирхэг амийн хүч үргэлж байдаг. Тэгээд чи тийм нөхцөлд орох бүрдээ байнга мэгшиж, цурхиран уйлж эхэлдэг ба дараа нь яахаа мэддэггүй. Та нарын зарим нь үнэхээр явах гэж хичээдэг ч явах гэж оролдох үед зүрх чинь зүсэгдэх шиг болж, газар дэлхийн хий үзэгдэл сүнсийг чинь булаачихсан мэт санагдаж, зүрх сэтгэл чинь тайван бус болж, амар заяа үзэхээ байдаг. Дараа нь чи өөрийн эрхгүй сэтгэлээ хатамжлан, Бурхан руу эргэн ирдэг… Чамд ийм туршлага байгаагүй юу? Зүрх сэтгэлээ уудалж чаддаг залуухан ах эгч нар: “Тийм ээ! Үүнийг би маш олон удаа туулсан, энэ талаар бодохоос ичиж байна!” гэж хэлнэ гэдэгт Би огт эргэлзэхгүй байна. Би өдөр тутмын амьдралдаа залуу ах эгч нарыгаа ойр дотнын минь хүмүүс гэж үзэхдээ үргэлж баяртай байдаг, яагаад гэвэл тэд тун гэнэн цайлган, маш ариун, хайр татам байдаг. Тэд Миний анд нөхөд шиг байдаг. Тийм учраас Би дотнын бүх хүнээ цуглуулан туйлын зорилго, төлөвлөгөөнийхөө тухай ярилцах боломжийг үргэлж эрэлхийлж байгаа. Бурханы хүсэл бидэн дээр гүйцэлдэж, улмаар бид бүгд хоорондоо ямар ч зааг, зай завсаргүй, мах цус мэт болох болтугай. “Өө Бурхан минь! Хэрвээ энэ Таны хүсэл юм бол бидэнд зөв орчныг өгөөч гэж гуйя, тэгснээр бид чин сэтгэлийнхээ хүслийг биелүүлж болох юм. Бага залуу, эрүүл ухаанаар дулимаг биднийг Та өршөөж, зүрх сэтгэл дэх хүч чадлаа зориулах боломж олгох болтугай!” гэж бид бүгд Бурханд залбирах болтугай. Энэ нь Бурханы хүсэл гэдэгт Би итгэж байна, учир нь Би аль дээр Бурханд залбирч, “Эцэг минь! Газар дэлхий дээр бид Таныг зогсолтгүй дуудаж, газар дээр Таны хүсэл удалгүй биелээсэй гэж хүсдэг. Би Таны хүслийг эрж

хаймаар байна. Та хийхийг хүссэн зүйлээ хийж, Над дээр даалгавраа даруйхан гүйцэлдүүлэх болтугай. Таны хүсэл удахгүй биелнэ гэвэл Таныг бидний дунд шинэ зам нээгээсэй гэж ч Би хүсэж байна! Таны ажил удахгүй гүйцэлдээсэй гэж л гуйя, бас ямар ч дүрэм журам үүнийг хойш татаж чадахгүй гэж итгэе!" гэж хэлсэн билээ. Өнөөдрийн Бурханы ажил энэ юм; Ариун Сүнсний алхдаг замыг чи харахгүй байна уу? Ахмад ах эгч нартай уулзах бүрд Надад үгээр илэрхийлшгүй дарамттай мэдрэмж төрдөг. Тэдэнтэй уулзах үед нийгэм ханхалж байгаа нь харагддаг; тэдний шашны үзэл, аливааг зохицуулах туршлага, ярьж байгаа байдал, хэрэглэдэг үг гэх мэт нь бүгд бухимдал төрүүлдэг. Тэд "мэргэн ухаанаар" дүүрэн мэт байдаг. Би хувьдаа ертөнцөд амьдрах гүн ухаанаар зэвсэглээгүй тул тэднээс үргэлж чадах чинээгээрээ зай барьдаг. Энэ хүмүүстэй уулзах болгондоо Би туйлдаж, духанд хөлс бурзайдаг; заримдаа маш их дарамтад ороод бараг амьсгалж ч чаддаггүй. Иймээс энэхүү аюултай мөчид Бурхан Надад сайхан гарах гарц өгдөг. Магадгүй энэ зүгээр л Миний эндүүрэл байх. Би Бурханд ашигтай зүйлд л анхаардаг; Бурханы хүслийг биелүүлэх л хамгийн чухал. Би энэ хүмүүсээс хол байдаг ч Бурхан Намайг тэдэнтэй уулз гэж шаардвал үүнийг мөн л дуулгавартай дагадаг. Тэд жигшүүртэй байдаг юм биш, харин тэдний "мэргэн ухаан", үзэл, ертөнцөд амьдрах гүн ухаан маш ой гутам. Би тэднээс аливааг яаж хийдгийг суралцах гэж биш, Бурханы даалгаврыг гүйцэлдүүлэх гэж тэнд байдаг. Бурхан Надад нэг удаа, "Газар дээр Эцэгийнхээ хүслийг биелүүлж, даалгаврыг нь гүйцэлдүүлэхээр л эрэлхийл. Өөр юу ч Чамд хамаагүй" гэж хэлсэн санагдаж байна. Үүнийг бодоод жаахан санаа амардаг юм. Учир нь хүний хэрэг явдал Надад үргэлж нэн ээдрээтэй санагддаг; үүнийг нь Би ойлгож чаддаггүй бөгөөд яах учраа хэзээ ч олдоггүй. Тиймээс тоймгүй олон удаа үүнд самуурч, хүн төрөлхтнийг үзэн ядсан; яагаад хүмүүс ийм ээдрээтэй байх ёстой юм бэ? Яагаад энгийн байж болдоггүй юм бэ? Тэгж ухаалаг байх гэж хичээх ямар хэрэгтэй юм бэ? Хүмүүстэй уулзах үе минь ихэнхдээ Надад өгсөн Бурханы даалгаварт үндэслэдэг. Цөөн хэдэн удаад тийм байгаагүй байж магад, гэхдээ Миний зүрх сэтгэлийн гүнд юу нуугдаж байгааг хэн мэдэх вэ?

Бурханд зүрх сэтгэлээрээ итгэх ёстой, өөрсдийн ашиг сонирхлыг анхаарах бус, харин Бурханы хүсэлд анхаарал хандуулах ёстой гэж Би хамт байгаа ах эгч нартаа олон удаа зөвлөсөн. Бурханы өмнө Би олон удаа шаналан уйлсан: Яагаад хүмүүс Бурханы хүсэлд анхаардаггүй юм бэ? Бурханы ажил ямар ч шалтгаангүйгээр шууд ул мөргүй алга болсон гэж үү? Яагаад гэдгийг нь ч Би мэддэггүй—энэ нь Миний оюун санаанд бараг оньсого болсон—хүмүүс Ариун Сүнс алхдаг замыг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй атлаа бусадтай тогтоосон хэвийн бус харилцаатайгаа яагаад зууралдсаар байдаг юм бэ? Иймэрхүү хүмүүсийг харахаар дотор муухайрдаг. Ариун Сүнсний замд найдахын оронд тэд хүний үйл хэрэгт анхаардаг. Бурхан үүнд сэтгэл ханамжтай байж чадах уу? Үүнд Би ихэвчлэн гунигладаг. Энэ нь бараг Миний ачаа болсон бөгөөд Ариун Сүнсийг ч бас түгшээдэг. Чи зүрх сэтгэлдээ ямар ч зэмлэл мэдэрдэггүй гэж үү? Бурхан бидний сүнсний нүдийг нээх

болтугай. Хүмүүсийг Бурханы ажил руу ороход замчилдаг Би: “Өө Эцэг минь! Таны хүсэл цөм нь байгаасай гэж Би хүсэж байна, Би Таны хүслийг хайж, Таны даалгаварт үнэнч баймаар байна, ингэснээр Та энэ бүлэг хүмүүсийг олж авч чадна. Та биднийг эрх чөлөөтэй нутагт аваачиж, тэгснээр Танд бид сүнсээрээ хүрэх болтугай, бидний зүрх сэтгэл дэх сүнслэг мэдрэмжийг Та сэрээх болтугай!” хэмээн Бурханы өмнө олон удаа залбирсан. Би Бурханы хүсэл биелээсэй гэж хүсдэг учраас Бурханы Сүнс биднийг үргэлжлүүлэн гэгээрүүлээсэй, бид Ариун Сүнсний удирдсан замаар алхаасай гэж тасралтгүй залбирдаг—учир нь Миний алхдаг зам бол Ариун Сүнсний зам юм. Тэгвэл Миний оронд өөр хэн энэ замаар алхаж чадах юм бэ? Энэ нь Миний ачааг бүр ч хүндрүүлдэг. Надад унах гэж байгаа мэт санагддаг ч Бурхан ажлаа хэзээ ч хойшлуулахгүй гэдэгт Би итгэдэг. Магадгүй Бурханы даалгавар гүйцэлдсэн цагт л бид зам салах байх. Тэгэхээр Бурханы Сүнсний үр нөлөөнөөс үүдэн Надад үргэлж өөр санагдаж ирсэн байх. Бурханд хийхийг хүсдэг ажил байх шиг байдаг ч энэ нь юу болохыг Би ухаарч чадахгүй л байна. Гэхдээ Би, газар дээр дотнын хүмүүсээс минь илүү хэн ч үгүй гэдэгт итгэдэг бөгөөд Бурханы өмнө тэд Миний төлөө залбирна гэдэгт итгэж, үүнд нь хэмжээлшгүй их талархдаг. Ах эгч нар үүнийг Надтай хамт хэлээч гэж хүсье: “Өө Бурхан минь! Сүүлчийн эрин үеийн хүмүүс биднээс Таны хүсэл бүрэн харагдаж, тэгснээр бид сүнсний амьдралаар ерөөгдөж, Бурханы Сүнсний үйл хэргийг үзэж, Түүний үнэн царайг харах болтугай!” Энэ алхамд хүрмэгцээ бид үнэхээр Сүнсний удирдамж дор амьдарч байх бөгөөд тэгсэн цагт л бид Бурханы үнэн царайг харж чадна. Өөрөөр хэлбэл, хүмүүс бүх үнэний жинхэнэ утга учрыг ойлгож чаддаг болж, хүний үзлийн дагуу бус, Бурханы Сүнсний хүслийн гэгээрлийн дагуу ойлгож, ухаарна. Энэ нь тэр чигтээ Бурханы Өөрийн ажил бөгөөд үүнд хүний ямар ч санаа байхгүй; энэ нь газар дэлхий дээр үйл хэргээ ил болгох Бурханы ажлын төлөвлөгөө бөгөөд газар дээрх Бурханы ажлын сүүлчийн хэсэг юм. Чи энэ ажилд нэгдэхийг хүсэж байна уу? Үүний нэг хэсэг байхыг хүсэж байна уу? Чи Ариун Сүнсээр төгс болгуулж, сүнсний амьдралыг эдлэхээр тэмүүлдэг үү?

Өнөөдөр анхдагч сууринаасаа гүнзгийрэх нь гол түлхүүр юм. Бид үнэн, үзэгдэл, амьдралд илүү гүнзгийрэх ёстой—гэвч ажлын энэ алхамд орохын тулд урьдын үзлээ хаях ёстой гэдгийг Би эхлээд ах эгч нарт сануулах ёстой. Өөрөөр хэлбэл, чи амьдардаг байдлаа өөрчилж, шинэ төлөвлөгөө гаргаж, шинээр эхлэх ёстой. Өнгөрсөн цаг үед эрхэм нандин байсан зүйлтэйгээ зууралдсаар байвал Ариун Сүнс чам дээр ажиллах боломжгүй бөгөөд амийг чинь тэтгэж бараг чадахгүй. Эрэлхийлж, орж, төлөвлөдөггүй хүмүүсийг Ариун Сүнс бүрмөсөн хаяна—тийм болохоор тэднийг эрин үед хаягдсан гэдэг. Бүх ах эгч Миний зүрх сэтгэлийг ойлгож чадна гэж найдъя, бас илүү олон “шинээр элсэгч” Бурхантай хамтран ажиллаж, энэ ажлыг хамтдаа дуусгахаар өндийн босно гэж найдъя. Бурхан биднийг ерөөнө гэдэгт Би итгэж байна. Иймээс Бурхан Надад илүү олон дотнын хүн өгч, тэгснээр Би газар дэлхийн өнцөг булан бүрд алхаж, бидний хооронд илүү их хайр байна

гэдэгт ч итгэж байна. Түүнчлэн бидний хүчин зүтгэлээс үүдэн Бурхан хаанчлалаа өргөжүүлнэ гэж итгэж байна; бидний энэ хүчин зүтгэл урьд өмнө байгаагүй түвшинд хүрч, Бурхан илүү олон залуу хүн олж аваасай гэж Би хүсэж байна. Үүний төлөө залбирахад илүү их цаг зарцуулаасай, бид зогсолтгүй залбирч, тэгснээр бүхий л амьдралаа Бурханы өмнө өнгөрүүлж, Бурхантай чадах чинээгээрээ ойр дотно байгаасай гэж Би хүсэж байна. Цаашид бидний дундуур хэзээ ч, юу ч бүү орог, бас Бурханы өмнө бид бүгд: “Хамтдаа шаргуу ажиллана! Эцсээ хүртэл үнэнч байна! Хэзээ ч хагацалгүй үргэлж цуг байна!” гэсэн тангараг өргөх болтугай. Ах эгч нар бүгд Бурханы өмнө ийм амлалт өгч, тэгснээр бидний зүрх сэтгэл хэзээ ч өөрчлөгдөхгүй, шийдвэр маань хэзээ ч гуйвахгүй гэж Би найдаж байна! Бурханы хүслийн төлөө Би дахин хэлье: Шаргуу ажиллацгаая! Бүх чадлаараа зүтгэцгээе! Бурхан биднийг гарцаагүй ерөөнө!

ЗАМ… 6

Бид Бурханы ажлын ачаар өнөөдөртэй золгосон болохоор Бурханы удирдлагын төлөвлөгөөн дэх амьд үлдэгсэд юм. Бурханы төлөвлөгөөний дагуу агуу улаан лууны улс орон устах учиртай тул өнөөдөр бид амьд үлдсэн нь Бурханы агуу өргөлт билээ. Гэхдээ Бурхан магадгүй өөр төлөвлөгөө гаргасан, эсвэл ажлынхаа өөр нэг хэсгийг явуулахыг хүсдэг байх гэж Би боддог тул өнөөдөр ч Би үүнийг тодорхой тайлбарлаж чаддаггүй—энэ нь тайлагдашгүй оньсого мэт байдаг. Гэвч ерөнхийдөө энэ бүлэг хүмүүс биднийг Бурхан урьдчилан тогтоосон бөгөөд бидэн дээр хийх өөр ажил Бурханд байгаа гэдэгт Би итгэсээр байна. “Таны хүсэл биелж, Та дахин нэг удаа бидэнд үзэгдэж, Өөрийгөө нуухгүй байх болтугай, тэгснээр бид Таны алдар суу, дүр төрхийг илүү тодорхой харж болох юм” гэж Тэнгэрээс бид бүгд гуйх болтугай. Бурхан биднийг замчилдаг зам шулуун биш, дүүрэн хонхорт хотгороор дүүрэн, нугачаат зам гэдгийг Би байнга мэдэрдэг; түүнчлэн зам хэдий чинээ их бартаатай байна, хайрын сэтгэлийг маань төдий чинээ илчилж чадна гэж Бурхан хэлдэг. Гэхдээ бидний хэн нь ч тийм зам нээж чадахгүй. Би туршлагаараа бартаатай, аюул осолтой олон замаар алхаж, асар их зовлон туулсан; заримдаа бүр туйлын их уй гашууд нэрвэгдэж, орь дуу тавимаар байдаг байсан ч өнөөг хүртэл энэ замаар алхсан юм. Энэ нь Бурханы удирдан хөтөлдөг зам гэдэгт Би итгэдэг тул бүх зовлонгийн шаналгааг туулж, урагшилсаар байдаг. Бурхан үүнийг тогтоосон тул хэн үүнээс зайлж чадах билээ? Би ямар ч ерөөл хүртье гэж гуйдаггүй; гагцхүү Бурханы хүслийн дагуу алхах учиртай замаараа алхаж чадах юм сан гэж л гуйдаг. Би бусдыг даган дуурайж, тэдний алхдаг замаар алхахаар эрэлхийлдэггүй; гагцхүү Өөрт оноогдсон замаар эцсийг нь хүртэл үнэнчээр алхахаар л чармайдаг. Би бусдаас тусламж гуйдаггүй; үнэнийг хэлэхэд, өрөөл бусдад тусалж ч чаддаггүй. Энэ асуудал дээр Би туйлын мэдрэмтгий байх шиг байна. Бусад хүн юу гэж

боддогийг Би мэдэхгүй. Учир нь хувь хүний зовох ёстой хэмжээ, өөрсдийн замаар алхах ёстой зайг Бурхан тогтоодог бөгөөд үнэндээ хэн ч өрөөл бусдад тусалж чадахгүй гэдэгт Би үргэлж итгэж ирсэн. Зарим махруу ах эгч маань Надад хайр байдаггүй гэж хэлж болох ч энэ зүгээр л Миний бодол юм. Хүмүүс Бурханы удирдамжид найдан өөрсдийн замаар явдаг бөгөөд ихэнх ах эгч маань Миний зүрх сэтгэлийг ойлгоно гэж Би итгэдэг. Бас Бурхан энэ тал дээр биднийг хавьгүй их гэгээрлээр хангаж, тэгснээр бидний хайр илүү ариун, бидний барилдлага илүү эрхэм нандин болно гэж Би найдаж байна. Энэ асуудал дээр бид будилалгүй, гагцхүү илүү тодорхой ойлголт олж авч, тэгснээр Бурханы манлайллын суурин дээр хүн хоорондын харилцаа тогтох болтугай.

Бурхан эх газрын Хятадад олон жил ажиллаж, эцэст нь биднийг өдий хүргэхийн тулд бүх хүнд асар их төлөөс төлсөн юм. Хүн бүрийг зөв зам руу замчлахын тулд хүн бүрийн хамгийн сул дорой байдаг газарт энэ ажил эхлэх ёстой гэж Би боддог; тэр үед л тэд эхний саадыг давж, цааш урагшилж чаддаг. Ингэсэн нь дээр биш үү? Олон мянган жилийн турш завхарсан Хятад үндэстэн өнөөг хүртэл амьд үлдсэн бөгөөд элдэв янзын “вирус” зогсолтгүй довтолж, газар сайгүй тахал мэт тарсан; хүмүүсийн харилцааг харахад л хүмүүсийн дотор олон “нян” отож байгаа нь хангалттай харагддаг. Ийм ягштал хаагдсан, вирусийн халдвар бүхий бүсэд ажлаа өрнүүлэх нь Бурханд туйлын хэцүү байдаг. Хүмүүсийн зан ааш, зуршил, аливааг хийдэг байдал, амьдралдаа илэрхийлдэг бүх зүйл, хүн хоорондын харилцаа бүгд тартагтаа тулж, хүний мэдлэг, соёл бүгд Бурханаар цаазлуулахдаа тулсан байдаг. Гэр бүл, нийгмээсээ суралцсан янз бүрийн туршлагыг бол дурдахын ч хэрэггүй—эдгээр нь бүгд Бурханы нүдээр буруутгагдсан байдаг. Учир нь энэ нутагт амьдардаг хүмүүс дэндүү олон вирус идсэн. Тэдний хувьд энэ нь байдаг л зүйл бөгөөд тэд үүнийг юман чинээ боддоггүй. Тиймээс нэг газар дахь хүмүүс хэдий чинээ завхарсан байна, хүн хоорондын харилцаа нь төдий чинээ хэвийн бус байдаг. Хүмүүсийн харилцаа явуулгаар дүүрэн бөгөөд тэд хүний махан идэшт чөтгөрүүдийн цайзад байгаа мэт нэг нэгнийхээ эсрэг хуйвалдаж, бие биеэ хөнөөдөг. Хий үзэгдлүүд хаа сайгүй тархсан ийм аймшиг дүүрэн газарт Бурханы ажлыг явуулахад туйлын хэцүү байдаг. Би хүмүүстэй уулзахаас үхтлээ айдаг бөгөөд Өөрийн зан чанараар тэдний “нэр төрд” халдах вий гэж ихэд эмээдэг тул хүмүүстэй уулзах ёстой болох үедээ Бурханд тасралтгүй залбирдаг. Энэ бохир сүнснүүд болчимгүй аашлах вий гэж зүрх сэтгэлдээ цаг ямагт айдаг тул Намайг хамгаалаач гэж Бурханд үргэлж залбирдаг. Бидний дунд элдэв янзын хэвийн бус харилцаа илэрхий байдаг бөгөөд энэ бүгдийг хараад зүрх сэтгэлд минь үзэн ядалт төрдөг, учир нь хүмүүс өөр хоорондоо үргэлж хүний “бизнес” хийж, Бурханы талаар хэзээ ч бодож үздэггүй. Би тэдний зан авирыг голдоо ортол үзэн яддаг. Эх газрын Хятадын хүмүүсээс гагцхүү завхарсан сатанлаг зан чанарыг харж болдог тул энэ хүмүүс дээр Бурхан ажиллах үед тэдний дотроос үнэ цэнтэй зүйл олох бараг боломжгүй; бүх ажлыг Ариун Сүнс хийдэг бөгөөд Ариун Сүнс л хүмүүсийг илүү их хөдөлгөж, тэдэн дээр ажилладаг. Энэ хүмүүсийг ашиглах

бараг боломжгүй; өөрөөр хэлбэл, хүмүүсийг хөдөлгөх Ариун Сүнсний ажлыг хүмүүсийн хамтын ажиллагаатай хавсруулан хийх боломжгүй. Ариун Сүнс зүгээр л хүмүүсийг хөдөлгөх гэж нөр их хөдөлмөрлөдөг, гэхдээ тэглээ ч гэсэн хүмүүс хөшүүн, мэдрэмжгүй хэвээр үлдэж, Бурхан юу хийгээд байгааг огт мэддэггүй. Иймээс эх газрын Хятад дахь Бурханы ажлыг тэнгэр газрыг бүтээх Бурханы ажилтай харьцуулахуйц юм. Хүмүүсийн дотор үнэ цэнтэй юу ч байдаггүй тул Бурхан бүх хүнийг дахин төрүүлж, тэдний бүх зүйлийг өөрчилдөг. Энэ үнэхээр сэтгэл шимширмээр. Энэ хүмүүсийн төлөө Би үргэлж: “Бурхан минь, энэ хүмүүсээс Таны агуу хүч чадал илчлэгдэж, тэгснээр Таны Сүнс тэдний сэтгэлийг асар их хөдөлгөж, тэгээд энэ хөшүүн, мунхаг зовогсод сэхээрч, үхширсэн нойрноосоо сэрж, Таны алдрын өдрийг харах болтугай” хэмээн гуниглан залбирдаг. Бид бүгдээрээ Бурханы өмнө залбирч, ийнхүү хэлэх болтугай: Өө Бурхан минь! Та биднийг дахин нэг удаа өршөөж, халамжилж, тэгснээр бидний зүрх сэтгэл Тан руу бүрэн эргэж, энэ бузар булай газраас ангижирч, өндийн босож, даалгасан зүйлийг тань гүйцэлдүүлж чадах болтугай. Бурхан биднийг дахин нэг удаа хөдөлгөж, тэгснээр бид Түүнээс гэгээрэл хүртэнэ гэж найдъя, мөн Бурхан биднийг өршөөж, улмаар зүрх сэтгэл маань аажмаар Бурхан руу эргэж, Бурхан биднийг олж авна гэж найдъя. Энэ бол бид бүгдэд нийтлэг байдаг хүсэл билээ.

Бидний алхдаг замыг тэр чигт нь Бурхан тогтоодог. Товчхондоо, Би эцсээ хүртэл энэ замаар лавтайяа алхана гэдэгтээ итгэдэг, учир нь Бурхан үргэлж Над руу мишээж, Бурханы гар Намайг үргэлж замчилж байх шиг байдаг. Иймээс Миний зүрх сэтгэлийг өөр юу ч сэвтээдэггүй бөгөөд иймд Би цаг үргэлж Бурханы ажилд анхаардаг. Бурханы өгсөн бүх даалгаврыг Би хамаг чадлаараа, үнэнчээр гүйцэтгэдэг бөгөөд Өөрт оногдоогүй ажилд хэзээ ч хөндлөнгөөс оролцдоггүй, мөн өөр хэн үүнийг хийх вэ гэдэгт ч оролцдоггүй—учир нь хүн бүр өөрсдийн гэсэн замаар алхаж, бусдын хэрэгт хошуу дүрэхгүй байх ёстой гэж Би итгэдэг. Би тэгж үздэг. Энэ магадгүй Миний зан аашнаас болдог байх, гэхдээ Би Эцэгийнхээ зарлигийг хэзээ ч сөрж зүрхлэхгүй учраас ах эгч нар маань Намайг ойлгож, уучилна гэж найдъя. Би Тэнгэрийн хүслийг эсэргүүцэж зүрхэлдэггүй. “Тэнгэрийн хүслийг эсэргүүцэж болохгүй” гэдгийг чи мартаа юу? Зарим хүн Намайг амиа бодсон гэж бодож болох ч Би Өөрийгөө Бурханы удирдлагын ажлын нэг хэсгийг гүйцэтгэхээр тусгайлан ирсэн гэж боддог. Би хүн хоорондын харилцаанд оролцох гэж ирээгүй; бусадтай яаж таарамж сайтай байхыг Би хэзээ ч сурч чадахгүй. Гэвч Бурханы даалгаврын хувьд Надад Бурханы удирдамж байдаг бөгөөд энэ ажлын эцсийг үзэх итгэл, тууштай байдал Надад бий. Магадгүй Би хэт “амиа бодож” байж болох ч хүн бүр санаачилга гарган Бурханы шулуун шударга, харамгүй хайрыг мэдэрч, Бурхантай хамтран ажиллахаар хичээнэ гэж Би найдаж байна. Бурханы сүр жавхлангийн хоёр дахь илрэлтийг бүү хүлээ; энэ нь хэнд ч сайнгүй. “Бурханы хүслийг биелүүлэхийн тулд хийх учиртай зүйлээ хийхдээ бид боломжтой бүхнийг хийх ёстой. Бид бүхэнд өгсөн Бурханы даалгавар өөр; үүнийг бид хэрхэн гүйцэтгэх

ёстой вэ?” хэмээн бид бодолцож үзэх ёстой гэж Би үргэлж боддог. Алхдаг зам чинь яг ямар болохыг чи ухаарах ёстой—энэ талаар тодорхой мэддэг байх нь нэн чухал. Та нар бүгдээрээ Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг хүсдэг тул өөрсдийгөө Бурханд даатгавал яасан юм бэ? Би анх Бурханд залбирахдаа бүхий л сэтгэл зүрхээ Түүнд өгсөн. Би сэтгэл шулуудсан зүйлээсээ үүдэн эцэг эх, эгч, ах, хамтран ажиллагсад гэх зэрэг эргэн тойрон дахь бүх хүнд анхаарал хандуулахаа бүр болиод, Миний хувьд тэд огт байхгүй мэт л болсон. Миний оюун санаа үргэлж Бурханд, Бурханы үг, эсвэл мэргэн ухааныг анхаардаг байлаа; зүрх сэтгэлд минь үргэлж эдгээр зүйл байж, зүрх сэтгэлийн минь хамгийн эрхэм нандин байр суурийг эзэлсэн. Иймээс амьдралын гүн ухаанаар дүүрэн хүмүүсийн хувьд Би цэвдэг, сэтгэл хөдлөлгүй нэгэн. Миний биеэ авч явдаг байдал, аливааг хийдэг арга зам, үйл хөдөлгөөн бүрд тэдний сэтгэл өвддөг. Би гэх хүн тайлагдашгүй оньсого мэтээр тэд Над руу жигтэй харц чулууддаг. Тэгээд дараа нь юу хийхийг минь мэдэлгүй, Би гэх хүнийг тэд сэтгэлдээ нууцхан цэгнэж байгаа. Тэдний хийдэг зүйл Миний замд хөндөлсөж яахан чадах билээ? Тэд атаархаж, зэвүүцэж, дооглож байж ч магад; ямартай ч энэ ертөнцөд Бурхан бид хоёроос өөр хэн ч байхгүй мэтээр Би асар их өлсөж цанган, Бурханы өмнө эцсээ хүртэл залбирдаг. Гадаад ертөнцийн хүчнүүд Намайг ямагт тойрон нягт бүчдэг ч Бурханаар хөдөлгөгдөх мэдрэмж ч бас Миний дотор огшдог. Энэ ацан шалаанд ороод Би Бурханы өмнө сөгдсөн: “Өө Бурхан минь! Би Таны хүсэлд дургүйцэж яахан чадах билээ? Таны нүд Намайг хүндтэй, шижир алт мэтээр хардаг атал харанхуйн хүчнээс Би ангижирч чадахгүй юм. Таны төлөө Би насан туршдаа зовж, Таны ажлыг амьдралынхаа мэргэжил болгомоор байна, бас Танд Өөрийгөө зориулах зүй зохистой амралтын газар хайрлаач гэж Танаас гуйя. Өө Бурхан минь! Би Танд Өөрийгөө өргөн барихыг хүсэж байна. Хүний сул талыг Та сайн мэдэх атлаа Өөрийгөө юунд Надаас нууна вэ?” Яг тэгэхэд Би хэнд ч мэдэгдэлгүй, сэвшээ салхинд анхилуун үнэрээ ханхлуулж буй уулын сараана цэцэг мэт байв. Харин Тэнгэр уйлж, Миний зүрх сэтгэл шимширсээр байлаа; Миний зүрх сэтгэл бүр ч их шаналж байх шиг санагдсан. Бүхий л хүчин, хүний бүслэлт гэгээн цагаан өдрөөр аянга цахих мэт байсан юм. Миний сэтгэлийг хэн ойлгож чадах билээ? Тиймээс Би Бурханы өмнө дахин нэг удаа очиж, “Өө Бурхан минь! Энэ бузар газарт Таны ажлыг явуулах ямар ч аргагүй юм гэж үү? Хяхалт хавчлагаас ангид, тав тухтай, өмөг түшигтэй орчинд бусад хүн яагаад Таны зүрх сэтгэлийг хайхарч чаддаггүй юм бэ? Би далавчаа дэлгэхийг хүсэвч нисэн одох яагаад ийм хэцүү байдаг юм бэ? Та зөвшөөрөхгүй байна гэж үү?” хэмээн хэлсэн. Би үүнээс болж олон хоног уйлсан ч гуньсан зүрх сэтгэлд минь Бурхан тайтгарал авчирна гэдэгт үргэлж итгэсэн. Миний түгшүүрийг хэн ч, хэзээ ч ойлгож байгаагүй. Магадгүй энэ нь Бурханаас шууд ирсэн ойлголт байх—Би дотроо үргэлж Бурханы ажлын төлөө гэсэн гал цогтой байж, бараг амсхийх завдалгүй явсан. Өнөөг хүртэл Би: “Өө Бурхан минь! Энэ нь Таны хүсэл юм бол Таны бүр ч агуу ажлыг явуулахад Та Намайг хөтлөх болтугай, улмаар энэ нь орчлон ертөнц даяар түгж, үндэстэн,

урсгал бүрд нээгдэж, тэгснээр Миний зүрх сэтгэл бага зэрэг амар амгаланг олж, Би насан туршдаа амар амгалан зүрх сэтгэлтэйгээр амрах газарт Таны төлөө амьдран, Таны төлөө саадгүй ажиллаж, Танд үйлчилж чадах болтугай" гэж залбирсаар байдаг. Энэ бол Миний чин зүрхний хүсэл. Ах эгч нар Намайг биеэ тоосон, ихэрхүү гэж хэлж магад; энэ нь баримт тул Би ч үүнийг хүлээн зөвшөөрнө—залуу хүмүүс гагцхүү биеэ тоосон байдаг. Иймээс Би юмыг баримтаас зөрүүлэлгүй, үнэхээр байгаагаар нь хэлдэг. Надаас чи залуу хүний зан авирын бүх онцлог шинжийг олж харж магадгүй, гэхдээ Би тайван, амгалан гэдгээрээ бусад залуу хүнээс өөр гэдгийг бас харж болох юм. Үүнийг Би сэдэв болгох гээгүй; Өөрийгөө мэддэгээс минь илүүтэй Бурхан Намайг мэддэг гэдэгт Би итгэдэг. Чин сэтгэлийн минь үг энэ бөгөөд ах эгч нар гомдохгүй гэж найдаж байна. Бид зүрх сэтгэлийн үгээ хэлж, дор бүрнээ юу эрэлхийлдгээ харж, Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээ харьцуулж, Бурханд шивнэдэг үгээ сонсож, зүрх сэтгэлдээ хамгийн эгшиглэнтэй сайхан дуу дуулж, зүрх сэтгэл дэх бахархлаа илэрхийлж, ингэснээр амьдрал маань улам сайхан болох болтугай. Өнгөрснийг мартаж, ирээдүйг хүсэн хүлээ. Бурхан бидэнд зориулж зам нээх болно!

ЗАМ… 7

Хөл доорх замыг маань илүү бат бөх, илүү бодитой байг гэсэндээ Бурхан бидэнд биечлэн зам нээж өгсөн удаа олон байдгийг бодит туршлагаараа бид олж хардаг. Учир нь энэ бол балар эрт цагаас хойш бидэнд Бурханы нээж өгсөн, олон арван мянган жилийн дараа манай үеийнхэнд өв уламжлагдан ирсэн зам билээ. Эцсийг нь хүртэл алхаагүй өвөг дээдсийнхээ энэ замыг бид ийнхүү хүлээн авсан юм. Үүний эцсийн үе шатаар алхуулах гэж Бурхан биднийг сонгожээ. Иймээс энэ замыг Бурхан бидэнд тусгайлан бэлдсэн бөгөөд бид ерөөгдсөн ч бай, золгүйтэлд өртсөн ч бай, өөр хэн ч энэ замаар алхаж чадахгүй. Үүнд Би Өөрийн ойлголтыг нэмье: Өөр тийш зугтах гэж оролдъё, өөр зам хайж олохоор хичээе гэж бүү бод, мөн байр сууринд бүү шуна, өөрийн хаанчлалыг байгуулахаар бүү хичээ—эдгээр нь бүгд уран зөгнөл юм. Миний үгийн талаар чамд урьдаас тогтсон зарим санаа байж магад, тийм тохиолдолд Би чамд тэгтлээ будилуу байхаа боль гэж зөвлөе. Үүнийг илүү их бодож тунгаасан чинь дээр; ухаалаг байх гэж бүү хичээ, сайн мууг бүү хольж хутга. Бурханы төлөвлөгөө биелмэгц үүндээ чи харамсана. Өөрөөр хэлбэл, Бурханы хаанчлал ирэхэд газар дэлхийн улс үндэстнүүд бүгд хэдэн хэсэг болж бут цохигдоно. Тэр үед, өөрийн чинь төлөвлөгөө ч бас үгүй болсон гэдгийг, гэсгээгдсэн хүмүүс бут цохигдоно гэдгийг чи олж харах бөгөөд үүгээр Бурхан зан чанараа бүрэн харуулна. Эдгээр зүйл Надад тов тодорхой байдаг, иймээс дараа нь Намайг бүү буруутгаасай гэсэндээ эдгээрийг чамд хэлэх ёстой гэж бодож байна. Өнөөдрийг хүртэл бид энэ замаар алхаж чадсан нь Бурханы тогтоосон зүйл,

иймээс өөрийгөө онц гойд юм уу азгүй гэж бүү бод—Бурханы өнөөгийн ажлын талаар хэн ч баталгаа хэлж болохгүй, эс тэгвээс чи хэдэн хэсэг болон бут цохигдоно. Би Бурханы ажлаар гэгээрсэн: Юу ч боллоо гэсэн Бурхан энэ бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгоно, Түүний ажил дахин хэзээ ч өөрчлөгдөхгүй, Бурхан энэ бүлэг хүмүүсийг замын төгсгөлд аваачиж, газар дэлхий дээрх ажлаа дуусгана. Бид бүгд үүнийг ойлгох ёстой. Ихэнх хүн “алсын хараатай байх” дуртай бөгөөд дур сонирхолд нь эцэс төгсгөл гэж үгүй. Бурханы өнөөдрийн тулгамдсан хүслийг хэн нь ч ойлгодоггүй тул тэд бүгд зугтахыг боддог. Тэд цөлд хэрэн хэсүүчлэхийг л хүсдэг алдуул морьд шиг байдаг; цөөн хэд нь хүний амьдралын замыг эрж хайхаар Канааны сайхан нутагт суурьшихыг хүсдэг. Хүмүүс сүү, бал урссан газарт орчхоод баясдаггүй юм бол өөр юу хүсдэг юм бэ? Үнэнийг хэлэхэд, Канааны сайхан нутгаас цааш цөл газар л бий. Хүмүүс амрах газар орчхоод ч үүрэгтээ үнэнч байж чаддаггүй; тэд зүгээр л янхнууд бус уу? Хэрэв энд Бурханаар төгс болгуулах боломжоо алдвал үүндээ чи насан туршдаа харамсаж, хязгааргүй их харуусна. Чи Канааны нутгийг ширтэн харсан ч эдэлж чадалгүй нударга зангидан, харуусал дүүрэн үхсэн Мосе шиг байх болно—ингэх нь ичгүүртэй гэж чи бодохгүй байна уу? Үүнийг ичмээр, бусдын доог болох зүйл гэж бодохгүй байна уу? Чи бусдаар доромжлуулахыг хүсээ юу? Чи амжилтад хүрэхийг хүсэхгүй байна уу? Бурханаар төгс болгуулсан, хүндэт, шулуун шударга хүн байхыг хүсэхгүй байна уу? Чи үнэхээр ямар ч хүсэл эрмэлзэлгүй юм гэж үү? Чи өөр замаар явахыг хүсдэггүй; тэгвэл бас чамд зориулж Бурханы тогтоосон замаар явахыг хүсэхгүй байна гэж үү? Чи Тэнгэрийн хүслийн эсрэг явж зүрхлэх үү? “Чадвар” чинь хэчнээн агуу ч бай хамаагүй, Тэнгэрт халдаж чи үнэхээр чадах уу? Бид өөрсдийгөө зохих ёсоор мэдэх гэж хичээсэн нь дээр гэж Би бодож байна. Бурханы нэг үг тэнгэр газрыг өөрчилж чадна, тэгэхээр өчүүхэн жижиг, эцэнхий нэг хүн Бурханы нүдэнд юу юм бэ?

Бурханыг эсэргүүцэх тусам чинь Бурхан Өөрийн сүр жавхлант зан чанарыг улам их харуулж, чамд “үзүүлдэг” гэсгээлт нь улам хатуу байх болно; Бурханыг дуулгавартай дагах тусам чинь Тэр чамайг улам их хайрлаж, хамгаална гэдгийг Би хувийнхаа туршлагаар олж харсан юм. Бурханы зан чанар шийтгэлийн хэрэгсэл мэт байдаг: Хэрвээ чи дуулгавартай дагавал эрүүл саруул байх болно; дуулгавартай дагахгүй, онгирох гэж үргэлж хичээн, байнга заль мэх гаргах үед чинь Бурханы зан чанар даруй өөрчлөгддөг. Тэрээр бүрхэг өдрийн нар мэт чамаас нуугдаж, уур хилэнгээ харуулна. Ойр тойрны олон бээрт тэнгэр цэлмэг, давлагаа усан мандалд долгиолох төдий байснаа урсгал гэнэт эрчээ авч, ус булингартан давлагаалах 6-р сарын цаг агаартай Түүний зан чанар бас адилхан байдаг. Бурханы ийм зан чанарын өмнө чи тийм болчимгүй байж зүрхлэх үү? Ариун Сүнсний ил тод ажиллаж байхыг хараад итгэл дүүрэн байдаг ч дараа нь Бурханы Сүнсэнд гэнэт орхигдох үедээ Түүний Сүнсний алга болсон зүгт эрж хайж, маш их шаналахдаа шөнө нойргүйддэг гэдгээ ах эгч та нарын ихэнх нь туршлагаараа харсан. Чи юу ч хийлээ гэсэн Түүний Сүнс хаашаа явсныг олж чаддаггүй—гэвч

дараа нь Тэр чамд гэнэт дахин үзэгддэг бөгөөд Эзэн Есүсийг Петр дахин нэг удаа гэнэт харсан шиг чи баярлан хөөрч, бараг дуу алдах шахдаг. Үүнийг чи маш олон удаа туулчхаад үнэхээр мартлаа гэж үү? Махбод болж, загалмайд цовдлогдоод, дараа нь дахин амилж, тэнгэр өөд гарсан Эзэн Есүс Христ үргэлж хэсэг зуур чамаас нуугдаад, дараа нь нэг хэсэг чамд үзэгддэг. Зөв шударга байдлаас чинь үүдэн Тэр Өөрийгөө чамд илчилж, нүглээс чинь үүдэн уурлаж, чамаас хагацдаг тул яагаад чи Түүнд улам их залбирдаггүй юм бэ? Пентэкостын дараа Эзэн Есүс Христэд газар дэлхий дээр биелүүлэх өөр даалгавар бий гэдгийг чи мэдээгүй гэж үү? Эзэн Есүс Христ махбод болж, газар дэлхий дээр ирж, загалмайд цовдлогдсон гэх баримтыг л чи мэддэг. Урьд нь чиний итгэдэг байсан Есүс ажлаа аль хэдийн өөр хэн нэгэнд даалгаад, энэ нь аль эрт гүйцэлдсэн, иймээс Эзэн Есүс Христийн Сүнс ажлынхаа өөр нэг хэсгийг хийхээр газар дэлхий дээр махбод хэлбэрээр дахин ирсэн гэдгийг чи хэзээ ч ухаараагүй. Энд Би нэг зүйл нэммээр байна—та нар одоо энэ урсгалд байгаа ч гэлээ энэ хүн бол Эзэн Есүс Христийн та нарт хайрласан Нэгэн гэж цөөн хэд чинь л итгэдэг гэдгийг Би зүрхэлж хэлье. Та нар Түүнийг таашахаа л мэддэг; Бурханы Сүнс газар дэлхий дээр дахин нэгэнтээ ирсэн гэдгийг та нар хүлээн зөвшөөрдөггүй, мөн өнөөдрийн Бурхан бол олон мянган жилийн өмнөх Есүс Христ гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Иймээс Би, та нар бүгд нүдээ аниатай алхаж байна, эцэст нь хаана ч очсон зүгээр л хүлээн зөвшөөрч, үүнд огт нухацтай хандахгүй байна гэж хэлдэг. Тиймээс та нар аман дээрээ Есүст итгэдэг ч өнөөдөр Бурханы гэрчлэл хийдэг Нэгнийг улайм цайм эсэргүүцэж зүрхэлдэг. Чи мунхаг биш үү? Өнөөдрийн Бурхан чиний алдааг тоодоггүй, чамайг ялладаггүй. Чи Есүст итгэдэг гэж хэлдэг, тэгвэл Эзэн Есүс Христ чинь чамайг өршөөж чадах байсан уу? Бурхан чиний уураа гаргаж, худал хэлж, хууран мэхлэх газар гэж бодоо юу? Чиний Эзэн Есүс Христ дахин нэг удаа илрэхдээ одоо яаж авирлаж байгаад чинь үндэслэн зөв шударга уу, ёрын муу юу гэдгийг чинь тогтооно. “Миний ах эгч нар” гэж хэлдэг зүйлийн минь талаар ихэнх хүн үзэлтэй болж хоцроод, Бурханы ажилладаг арга барил өөрчлөгдөнө гэж итгэдэг. Ийм хүмүүс үхлээ дуудаж байгаа бус уу? Бурхан Сатаныг Бурхан Өөрөө мөн хэмээн гэрчилж чадах уу? Үүгээр чи Бурханыг яллаж байгаа бус уу? Зүгээр л хэн ч хамаагүй Бурхан Өөрөө болж чаддаг гэж чи бодоо юу? Хэрвээ чи үнэхээр мэддэг бол ямар ч үзэлгүй байх байсан. Библид “Бүх зүйл Түүний төлөө байдаг, бүх зүйл Түүнээс гаралтай байдаг. Тэр олон хөвгүүнийг алдар луу аваачна, Тэр бол бидний Удирдагч …” гэх хэсэг бий. Иймээс Тэр биднийг ах дүүс гэж дуудахдаа огт ичдэггүй. Чи эдгээр үгийг амархан цээжээр уншиж чаддаг байж болох ч үнэндээ юу гэсэн утгатай болохыг нь ойлгодоггүй. Чи нүдээ аниад Бурханд итгэж байгаа бус уу?

Манай үеийнхэн өмнөх үеийнхний дуусгаагүй замаар явж, хэдэн мянган жилийн өмнөх Бурхан буюу бидний дунд байж, бүх зүйлд элбэг дэлбэг байгаа Бурханы дахин илрэхийг харж чадах ерөөлтэй гэдэгт Би итгэдэг. Чи энэ замаар алхана гэж хэзээ ч төсөөлж чадахгүй байх байсан—энэ чиний чадах зүйл гэж үү? Энэ замыг

Ариун Сүнс шууд удирддаг, үүнийг Эзэн Есүс Христийн долоо дахин эрчимжсэн Сүнс удирддаг бөгөөд өнөөдрийн Бурханы чамд нээж өгсөн зам энэ юм. Хэдэн мянган жилийн өмнөх Есүс чиний өмнө дахин гарч ирнэ гэж зүүдэнд чинь ч ороогүй байх. Чиний сэтгэл ханахгүй байна уу? Хэн Бурхантай нүүр тулан уулзаж чаддаг билээ? Бүлэг маань Бурханаас илүү их ерөөл хүртээсэй, бид Бурханы таалалд нийцэж, Түүгээр авхуулаасай гэж Би үргэлж залбирдаг, гэхдээ бас илүү агуу илчлэл харахын тулд биднийг гэгээрүүлэхийг Бурханаас гуйн өөрсдийнхөө төлөө гашуун нулимс унагасан удаа ч тоо томшгүй олон бий. Бурханыг хуурах гэж цаг ямагт оролдон, хэзээ ч, юуг ч эрмэлздэггүй, аль эсвэл махан биедээ анхаарч, өөрсдийгөө анхаарлын төвд оруулахын тулд ашиг сонирхол, нэр төрийн төлөө зүтгэдэг хүмүүсийг хараад Би зүрх сэтгэлдээ асар их шаналал мэдрэхээс өөр яах билээ? Хүмүүс яагаад ийм мэдрэлгүй байж чаддаг юм бэ? Миний ажил үнэхээр ямар ч үр нөлөөгүй байсан юм гэж үү? Үр хүүхэд чинь чиний эсрэг тэрсэлж, ачлалгүй байсан бол, мөс чанараар дулимаг байж, өөрсдийгөө л анхаарч, чиний сэтгэлийг хэзээ ч хайхралгүй, өсөж том болоод чамайг гэрээсээ хөөсөн бол тэр үед чамд ямар санагдах вэ? Үр хүүхдээ өсгөх гэж урсгасан цус, хөлс, гаргасан золиослолоо санаад хацрыг чинь даган нулимс мэлмэрэх байсан бус уу? Иймээс Би Бурханд тоо томшгүй олон удаа залбирч, “Хүндэт Бурхан минь! Ажлын тань төлөө ачаа үүрдэг эсэхийг минь Та л мэднэ. Үйлдэл минь Таны хүсэлд нийцэхгүй байх үед Та Намайг сахилгажуулж, төгс болгож, Надад мэдүүлдэг. Таныг удалгүй алдрыг олж, тэр хүмүүсийг олж авч, ажил тань Таны хүслийг биелүүлж, төлөвлөгөө тань эрт гүйцэлдэг гэсэндээ энэ хүмүүсийн сэтгэлийг илүү их хөдөлгөөч гэж л Танаас Би хүсдэг” гэсэн юм. Бурхан хүмүүсийг гэсгээлтээр байлдан дагуулахыг хүсдэггүй, мөн хүмүүсийг үргэлж хүчээр залж чиглүүлэхийг хүсдэггүй. Хүмүүс үгийг нь дуулгавартай дагаж, сахилга баттай байдлаар ажиллаж, үүгээр Өөрийнх нь хүслийг хангаасай гэж Бурхан хүсдэг. Гэхдээ хүмүүс ямар ч ичгүүргүй бөгөөд байнга Бурханы эсрэг тэрсэлдэг. Бид Бурханыг сэтгэл хангалуун байлгах хамгийн энгийн арга замыг олж, өөрөөр хэлбэл, Түүний бүх зохицуулалтыг дуулгавартай дагасан нь дээр гэж Би боддог. Хэрвээ чи үнэхээр ингэж чадвал төгс болгуулна. Энэ амар хялбар, баяр баясалтай зүйл биш үү? Явах учиртай замаараа яв; бусдын хэлдэг үгэнд бүү анхаар, хэт их юм бүү бод. Ирээдүй, хувь заяа чинь чиний гарт байгаа гэж үү? Чи үргэлж зугтахаар оролдон, ертөнцийн замаар явахыг хүсдэг мөртөө яагаад гарч чаддаггүй юм бэ? Яагаад олон жилийн турш салаа зам дээр сэтгэл чинь хоёрдоод, эцэст нь дахин нэг удаа энэ замыг сонгодог юм бэ? Олон жил тэнүүчилсний эцэст яагаад чи одоо өөрийн эрхгүй энэ гэрт эргэн ирсэн юм бэ? Энэ чамаас шалтгаалдаг гэж үү? Энэ урсгал дахь та нар Надад итгэхгүй байгаа бол үүнийг сонс: Хэрвээ чи явахаар төлөвлөж байгаа бол Бурхан чамайг явуулах эсэхийг хар, Ариун Сүнс чамайг яаж хөдөлгөхийг хар—үүнийг өөрөө мэдэр. Шулуухан хэлэхэд, чи золгүйтэл тууллаа ч гэсэн энэ урсгалд туулах ёстой, зовлон байвал энд, өнөөдөр зовох ёстой; чи өөр хаашаа ч явж чадахгүй. Үүнийг чи

тодорхой ойлгов уу? Чи хаачих юм бэ? Энэ бол Бурханы захиргааны зарлиг. Энэ бүлэг хүмүүсийг Бурхан сонгосон нь ямар ч утга учиргүй гэж чи бодоо юу? Бурхан өнөөдрийн ажилдаа амархан уурладаггүй—гэхдээ хүмүүс төлөвлөгөөг нь үймүүлэх гэж оролдвол Түүний царай нэн даруй өөрчлөгдөн, гэрэлтэж байснаа барайдаг. Иймээс буурь суурьтай байж, Бурханы зохион байгуулалтад захирагдаж, өөрийг чинь бүрэн төгс болгох боломжийг Бурханд олго гэж Би чамд зөвлөе. Ингэдэг хүмүүс л ухаалаг.

ЗАМ… 8

Бурхан хүн төрөлхтөнтэй харилцаж, хүмүүстэй цуг амьдрахаар газар дэлхий дээр ирснээс хойш ганц, хоёрхон хоног болсон юм биш. Магадгүй энэ хугацаанд хүмүүс Бурханы талаар сайн мэддэг болж, Бурханд үйлчлэх цөөнгүй ойлголт олж авч, Бурханд итгэхдээ хашир туршлагатай болдог байх. Ямартай ч хүмүүс Бурханы зан чанарыг их бага хэмжээнд ойлгодог бөгөөд өөрсдийн зан чанарыг ч мөн үй олон арга замаар илэрхийлдэг. Миний харж байгаагаар, Бурхан загвар болгон ашиглахад хүмүүсийн янз бүрийн илрэл хангалттай бөгөөд лавлагаа болгон ашиглахад оюуных нь үйл ажиллагаа хангалттай юм. Энэ нь хүн, Бурхан хоёрын хамтын ажиллагааны нэг тал байж болох бөгөөд үүнийг хүн мэддэггүй тул Бурханы найруулсан энэ үзүүлбэр маш тод томруун, амьдралд ойрхон болдог. Би энэ жүжгийн ерөнхий найруулагчийн хувиар ах эгч нартаа эдгээр зүйлийг хэлж байна—бид үүнд тоглосны дараа дор бүрнээ өөрсдийн бодол, мэдрэмжийг ярьж, энэхүү жүжиг дотор нэг бүр маань амьдралаа хэрхэн туулдаг тухай ярилцаж болох юм. Магадгүй бид зүрх сэтгэлээ уудалж, үзүүлбэрийн урлагийн талаар ярилцаж, Бурхан хүн болгоныг хэрхэн замчилдгийг харах цоо шинэ төрлийн бага хурал хийсэн нь дээр байх, тэгснээр бид дараачийн тоглолтод урлагийнхаа илүү өндөр түвшнийг илэрхийлж, дор бүрнээ өөрсдийн дүрийг чадах чинээгээрээ гүйцэтгэж, Бурханы урмыг хугалахгүй байж чадна. Ах эгч нар минь үүнийг нухацтай хүлээж авна гэж Би найдаж байна. Үүнд хэн ч хөнгөн хуумгай хандах ёсгүй, учир нь дүрээ сайн бүтээнэ гэдэг ганц, хоёр хоногт хүрч болох зүйл биш; үүний тулд урт удаан хугацаанд амьдрал туулж, бодит амьдралдаа илүү гүнзгий орж, янз бүрийн амьдралын бодит туршлагатай болох шаардлагатай. Тэгж байж л бид тайзан дээр гарч болно. Би ах эгч нартаа найдлага дүүрэн байна. Та нар зүрх алдаж, шантрахгүй, Бурханыг юу ч хийлээ гэсэн ассан гал шиг байж, Бурханы ажил бүрэн илчлэгдэн, Бурханы найруулдаг жүжиг эцсийн төгсгөлдөө хүртэл хэзээ ч бүлээн байлгүй, эцсээ хүртэл зүтгэнэ гэж Би итгэж байна. Би та нараас өөр юу ч шаарддаггүй, та нарыг гагцхүү хатуужилтай байж, үр дүнг хүлээн тэсвэр үл алдаж, Надтай хамтран ажиллаж, ингэснээр хийх учиртай ажил минь сайн хийгдэж, хэн ч саад болж, үймээн үүсгэхгүй гэж л найддаг. Ажлын энэ хэсэг дуусах үед Бурхан та нарт бүх зүйлийг илчилнэ. Би

ажлаа дуусгасны дараа Бурханд тайлан өгөхдөө та нарын гавьяаг Бурханы өмнө танилцуулна. Ингэсэн нь дээр биш үү? Өөрсдийнхөө зорилгод хүрэхийн тулд бие биедээ тусална гэдэг хүн бүрийн хувьд төгс шийдэл биш үү? Одоо үе бол та нараас төлөөс төлөхийг шаарддаг хэцүү бэрх цаг. Би одоо найруулагч болохоор та нарын хэн нь ч үүнд уцаарлаагүй гэж найдаж байна. Би ийм ажил хийж байгаа. Магадгүй нэг өдөр Би илүү зохистой “ажлын хэсэгт” шилжиж, та нарыг хүнд байдалд оруулахаа болино. Та нарын харахыг хүсдэг бүхнийг харуулж, сонсохыг хүсдэг бүхнийг олгоно. Гэхдээ одоо тэгэхгүй. Өнөөдрийн ажил нь ийм ажил бөгөөд Би та нарыг дураар нь дургиулж, хүссэн бүхнээ хий гэж зөвшөөрч чадахгүй. Тэгвэл Миний ажил хэцүүднэ; үнэнийг хэлэхэд, ажлаас минь ямар ч үр өгөөж гарахгүй, мөн та нарт ямар ч ашиг тус болохгүй. Иймээс өнөөдөр та нар “шударга бус байдлыг” амсах ёстой. Цаг нь ирж, Миний ажлын энэ үе шат дуусах үед Би чөлөөлөгдөж, ийм хүнд ачаа үүрэхгүй, тэгээд та нарын хүссэн бүхнийг зөвшөөрнө; та нарын аминд ашиг тустай байгаа цагт гуйсан зүйлийг чинь биелүүлнэ. Өнөөдөр Би хүнд хариуцлага хүлээлээ. Би Эцэг Бурханы тушаалыг сөрж болохгүй, мөн ажлынхаа төлөвлөгөөг нурааж болохгүй. Ажлын хэрэг явдлаар хувийн асуудлаа зохицуулж болохгүй—та нар бүгд Намайг ойлгож, уучилна гэж найдъя, учир нь Миний хийдэг бүхэн Эцэг Бурханы хүслийн дагуу байдаг; Тэр юу ч хүссэн бай, хий гэсэн бүхнийг нь Би хийдэг бөгөөд Түүний уур, хилэнг өдөөхийг хүсдэггүй. Би хийх учиртай зүйлээ л хийдэг. Иймээс та нарт, ахиад жаахан тэс гэж Эцэг Бурханы өмнөөс зөвлөе. Хэн ч санаа зовох хэрэггүй. Хийх хэрэгтэй зүйлээ дуусгасны минь дараа та нар хүссэн бүхнээ хийж, дуртай юм бүхнээ харж болно—харин Би хийх хэрэгтэй ажлаа гүйцэлдүүлэх ёстой.

Ажлын энэ үе шатанд биднээс туйлын их итгэл, хайр шаардагддаг. Бид болгоомжгүй байвал бүдрэх боломжтой, учир нь ажлын энэ үе шат өмнөх алхмуудаас өөр: Бурханы төгс болгож буй зүйл нь нүдэнд үзэгдэхгүй, гарт баригдахгүй, хүн төрөлхтний итгэл юм. Бурханы хийдэг зүйл бол үгийг итгэл, хайр, амь болгон хувиргах явдал. Хүмүүс олон зуун цэвэршүүлэлт туулаад, Иовоос илүү итгэл эзэмшдэг цэгт хүрэх ёстой. Тэд Бурханыг хэзээ ч орхилгүйгээр асар их зовлон, элдэв янзын тамлалтыг тэсвэрлэх ёстой. Тэд үхэн үхтлээ дуулгавартай байж, Бурханд асар их итгэх үед Бурханы ажлын энэ үе шат гүйцэлддэг. Энэ Миний хариуцсан ажил тул ах эгч нар минь Миний хүндрэл бэрхшээлийг ойлгож, Надаас өөр юу ч гуйхгүй гэж найдаж байна. Энэ бол Эцэг Бурханы Надад тавьсан шаардлага бөгөөд энэ бодит байдлаас Би зайлсхийж чадахгүй; хийх учиртай ажлаа хийх ёстой. Та нар хүчээр тулгасан дүгнэлт, гажуудсан логик ашиглахгүй, илүү ажигч гярхай байж, асуудлыг хэт энгийнээр харахгүй гэж л найдъя. Та нарын сэтгэхүй дэндүү томоогүй, дэндүү гэнэн. Бурханы ажил та нарын төсөөлдөг шиг тийм энгийн байдаггүй, Бурхан зүгээр л хүссэн бүхнээ хийдэг юм биш; тэгдэг байсан бол Түүний төлөвлөгөө сүйрэх байсан юм. Та нар тэгж хэлэхгүй юу? Би Бурханы ажлыг хийж байна. Зүгээр л хүмүүст хар бор ажил хийж өгч, хиймээр

байгаа бүхнээ хийж, юм хийх эсэхээ биечлэн зохицуулж байгаа юм биш. Өнөөдөр юм тийм хялбар байдаггүй. Эцэг минь Намайг найруулагчаар ажиллуулах гэж явуулсан—үүнийг Би Өөрөө зохицуулж, сонгосон гэж та нар бодоо юу? Хүний санаа Бурханы ажилд үргэлж саад болох гээд байдаг учраас хэсэг хугацаанд ажилласны минь дараа хүмүүс Миний биелүүлж чадахааргүй олон хүсэлт гаргаж, Миний талаарх бодлоо өөрчилдөг. Та нар бүгд ийм санааныхаа тухай тодорхой мэддэг байх учиртай; Би тэдгээрийг нэг бүрчлэн хөндөхгүй, харин Өөрийн хийдэг ажлыг л тайлбарлаж болох юм. Үүнд Миний сэтгэл огтхон ч шархалдаггүй. Та нар үүнийг ойлгомогцоо хүссэнээрээ бодож болно. Би огт эсэргүүцэхгүй, учир нь Бурхан ингэж ажилладаг; Би энэ бүхнийг тайлбарлах албагүй. Би зүгээр л үгийн ажил хийж, ажиллаж, үгийн удирдамжаар ийм жүжиг тоглох боломж олгохоор ирсэн. Би өөр юу ч хэлэх хэрэггүй, мөн өөр юу ч хийж чадахгүй. Би хэлэх ёстой бүхнээ тайлбарласан бөгөөд та нарын юу бодох нь хамаагүй, үүнийг Би хайхардаггүй. Гэхдээ Бурханы ажил та нарын төсөөлдөг шиг энгийн биш гэдгийг мөн л сануулмаар байна. Хүмүүсийн үзэлтэй нийцэхгүй байх тусам ач холбогдол нь улам гүн гүнзгий байдаг; хүмүүсийн үзэлтэй нийцтэй байх тусам үнэ цэн нь улам бага, бодит ач холбогдол илүү дутмаг байдаг. Энэ үгийг анхааралтай бодож үз—энэ талаар хэлэх үг минь ингээд гүйцлээ. Та нар бусдад нь өөрсдөө дүн шинжилгээ хийж болно. Үүнийг Би тайлбарлахгүй.

Бурхан аливааг тодорхой нэг байдлаар хийдэг гэж хүмүүс төсөөлдөг, гэхдээ өнгөрсөн нэг жил орчмын хугацаанд Бурханы ажлаас бидний үзэж, туулсан зүйл үнэхээр хүний үзэлд нийцэж байсан гэж үү? Дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш өнөөг хүртэл Бурханы ажлын үе шат, дүрмийг ухаарч чадсан ганц ч хүн байхгүй. Хэрэв тэгж чадсан юм бол өнөөдөр Бурхан ийм байдлаар ажилладгийг шашны удирдагчид яагаад ойлгодоггүй юм бэ? Өнөөдрийн бодит байдлыг яагаад ийм цөөхөн хүн ойлгодог юм бэ? Бурханы ажлыг хэн ч ойлгодоггүй гэдгийг бид үүнээс харж болно. Хүмүүс Бурханы Сүнсний удирдамжийн дагуу л үйлдэх ёстой; Бурханы ажилд зүгээр л хатуу чанд байдлаар дүрэм хэрэглэх ёсгүй. Чи Есүсийн дүр болон ажлыг аваад Бурханы өнөөгийн ажилтай харьцуулбал иудейчүүд Есүсийг Еховатай харьцуулахаар оролдсонтой яг адилхан. Ингэснээрээ та нар алдах бус уу? Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил ямар байхыг Есүс ч мэдээгүй; Есүс Өөрийнх нь гүйцээх хэрэгтэй ажил бол цовдлуулах ажил гэдгийг л мэдэж байсан. Тэгэхээр бусад нь яаж мэдэж чадах юм бэ? Ирээдүйд Бурхан ямар ажил хийхийг яаж мэдэж чадах юм бэ? Сатанд эзэмдүүлсэн хүмүүст Бурхан төлөвлөгөөгөө задалж яаж болох юм бэ? Энэ нь мунхаг хэрэг биш үү? Бурхан Өөрийнх нь хүслийг мэдэж, ойлгохыг чамаас шаарддаг. Харин ирээдүйнх нь ажлыг бодолцож үз гэж шаарддаггүй. Бид Бурханд итгэхдээ л анхаарч, Бурханы удирдамжийн дагуу үйлдэж, бодит бэрхшээлийг зохицуулахдаа прагматик байж, Бурханыг хүнд байдалд оруулахгүй, мөн Түүнд төвөг удахгүй л байх хэрэгтэй. Бид хийх учиртай зүйлээ хийх ёстой; Бурханы өнөөгийн ажил дотор байж чадаж байгаа цагт тэр нь хангалттай! Би та нарыг ийм

замаар замчилдаг. Хэрэв бид цааш урагшлахад л анхаарвал Бурхан бидний ганцтай нь ч эвгүй харьцахгүй. Өнгөрсөн жил та нар ер бусын туршлагаараа асар олон зүйл олж авсан; үүнийг хүндээр хүлээж авахгүй гэдэгт чинь Би итгэж байна. Та нарыг залж чиглүүлж байгаа зам маань Миний ажил, Миний үүрэг бөгөөд үүнийг Бурхан аль эрт тогтоосон тул бид өнөөг хүртэл ийм хол явах тавилантай байсан юм. Үүнийг хийж чадсан маань бидний агуу ерөөл бөгөөд энэ хэдийгээр дардан зам байгаагүй ч бидний барилдлага үүрд мөнх байж, үеэс үед уламжлагдана. Уухай, инээдийг ч, уй гуниг, нулимсыг ч бүгдийг нь сайхан дурсамж болгоё! Миний ажлын өдөр хоног тоотой гэдгийг та нар мэдэж байгаа байх. Надад ажлын олон төсөл байдаг болохоор та нартай байнга хамт байж чадахгүй. Та нар Намайг ойлгож чадна гэж найдъя—яагаад гэвэл бидний анхны барилдлага өөрчлөгдөөгүй. Би нэг л өдөр та нарын дунд дахин нэгэнтээ гарч ирж магадгүй бөгөөд та нар Намайг хүнд байдалд оруулахгүй гэж найдаж байна. Эцсийн эцэст Би та нараас өөр. Би ажлынхаа төлөө газар сайгүй аялдаг бөгөөд зочид буудлуудад зүгээр суун амьдралаа өнгөрөөдөггүй. Та нар ямар ч байлаа гэсэн Би хийх ёстой зүйлээ л хийдэг. Урьд нь хуваалцсан зүйлс маань бидний барилдлагын цэцэг болно гэж Би найдаж байна.

Энэ замыг Би нээсэн гэж хэлж болно, зовлонтой ч, жаргалтай ч Би энэ замыг удирдан залсан. Бид өнөөдөрт хүрсэн нь бүгд Бурханы нигүүлслийн ач юм. Зарим нь Надад талархаж, зарим нь Миний талаар гомдоллож магад—гэхдээ үүний аль нь ч хамаагүй. Би гагцхүү энэ бүлэг хүмүүст биелэх ёстой зүйл биелсэн байхыг л хармаар байна. Энэ л тэмдэглүүштэй зүйл. Иймээс Надад гомдоллодог хүмүүст Би өш санадаггүй; Бурханы зүрх сэтгэлийг удахгүй амраахын тулд ажлаа аль болох хурдан дуусгахыг л Би хүсдэг. Тэр үед Би ямар ч хүнд ачаа үүрэхгүй бөгөөд Бурханы зүрх сэтгэлд ямар ч зовнил байхгүй байна. Та нар хамтын ажиллагаагаа сайжруулахад бэлэн үү? Бурханы ажлыг сайн хийхээр зорьсон нь дээр биш үү? Энэ хэсэг хугацаанд бид тоо томшгүй олон бэрхшээл туулж, элдэв янзын баяр гуниг мэдэрсэн гэхэд хилсдэхгүй. Ерөнхийдөө та нарын дор бүрийн гүйцэтгэл үндсэндээ стандартад хүрсэн. Магадгүй ирээдүйд та нараас илүү сайн ажил шаардагдана, гэхдээ Миний талаар бүү бодлогошир; зүгээр л хийх ёстойгоо хий. Миний хийх хэрэгтэй зүйл бараг гүйцсэн; та нар цаг ямагт үнэнч хэвээр байж, Миний ажлыг санагалзахгүй гэж найдъя. Би зүгээр л ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлэхээр ирсэн болохоос яавч Бурханы ажлыг бүгдийг нь хийх гээгүйг та нар мэдэх ёстой. Та нар үүнийг тодорхой мэдэж, өөр санаа оноогүй байх ёстой. Бурханы ажлыг хийж гүйцээхэд илүү олон арга зам шаардлагатай; та нар Надад үргэлж найдаад байж болохгүй. Ехова юм уу Есүсийг төлөөлдөггүй ажлын нэг хэсгийг л хийхээр ирсэн гэдгийг маань та нар аль хэдийн ухаарсан байх; Бурханы ажил олон үе шатанд хуваагддаг тул та нар хэт хөшүүн байх ёсгүй. Ажиллаж байхад минь та нар Намайг сонсох ёстой. Эрин үе болгонд Бурханы ажил өөрчлөгддөг; эдгээр нь бүгд нэгэн хэвийн байдаггүй бөгөөд тухай бүрдээ улиг болсон зүйл байдаггүй. Харин үе шат

болгонд Бурханы ажил эрин үед тохирдог бөгөөд эрин үе өөр байгаагаас үүдэн өөрчлөгддөг. Иймээс та нар энэ эрин үед төрсөн тул Бурханы үгийг идэж ууж, эдгээр үгийг унших ёстой. Миний ажил өөрчлөгдөх өдөр ирж магадгүй, тэгсэн тохиолдолд та нар зохих ёсоор урагшилсаар байх ёстой; Бурханы ажил буруутах аргагүй. Гадаад ертөнц яаж өөрчлөгдөхийг бүү анхаар; Бурхан буруутах аргагүй бөгөөд Бурханы ажил буруутах аргагүй. Зүгээр л заримдаа Түүний хуучин ажил өнгөрөн одож, шинэ ажил нь эхэлдэг. Гэвч тэглээ гээд шинэ ажил ирсэн болохоор хуучин ажил буруу гэсэн үг биш. Энэ бол төөрөгдөл! Бурханы ажлыг зөв, буруу гэж хэлж болохгүй, гагцхүү өмнөх, хойдох гэж л хэлж болно. Бурханд итгэдэг хүмүүсийн итгэлд зориулсан удирдамж энэ бөгөөд үүнд хөнгөн хуумгай хандах ёсгүй.

ИТГЭГЧИД ЯМАР ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ УЧИРТАЙ ВЭ

Бурханд анх итгэж эхэлснээсээ хойш хүний олж авсан зүйл юу вэ? Чи Бурханы талаар юу мэдэж авсан бэ? Бурханд итгэх итгэлийнхээ улмаас чи хэр их өөрчлөгдсөн бэ? Хүний Бурханд итгэх итгэл нь зөвхөн сүнсний аврал болоод махан биеийн сайн сайхны төлөө биш, мөн энэ нь Бурханы хайраар дамжуулан амьдралаа баяжуулах гэх мэт ч биш гэдгийг одоо та нар бүгд мэдэж байгаа. Үүний дагуу, хэрвээ чи махан биеийн сайн сайхны төлөө, эсвэл түр зуурын таашаалын төлөө Бурханыг хайрладаг бол эцэст нь Бурханыг гэсэн хайр чинь оргилдоо хүрч, чи юу ч гуйгаагүй байсан ч гэсэн чиний эрж хайж буй энэ хайр нь ариун бус хайр хэвээр байх бөгөөд Бурханд таашаагдахгүй юм. Өөрсдийн уйтгартай амьдралыг баяжуулж, зүрх сэтгэл дэх хоосон орон зайгаа дүүргэхийн тулд Бурханыг хайрлах хайрыг ашигладаг хүмүүс нь үнэхээр Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг хүмүүс биш, харин амар хялбар амьдралд шунадаг хүмүүс юм. Ийм төрлийн хайр нь албадсан, сэтгэлийн баяр хөөрийн төлөөх эрэл хайгуул бөгөөд Бурханд ийм төрлийн хайр хэрэггүй. Тэгвэл чиний хайр ямар төрлийн хайр нь вэ? Юуны төлөө чи Бурханыг хайрладаг вэ? Бурханыг гэсэн жинхэнэ хайр чамд одоо хэр их байгаа вэ? Та нарын олонхын чинь хайр дээр дурдсантай адил байдаг. Ийм хайр нь зөвхөн тухайн байдлыг л хадгалдаг; энэ нь хувиршгүй байж чаддаггүй, мөн хүнд үндэслэж ч чаддаггүй. Ийм төрлийн хайр нь цэцэглэснийхээ дараа жимслэлгүй хатаж ганддаг цэцэгтэй адил. Өөрөөр хэлбэл, ийм байдлаар Бурханыг нэгэнтээ хайрласны дараа өмнөх замд чинь чамайг удирдан хөтлөх хэн ч байхгүй бол чи нуран унана. Хэрвээ чи Бурханыг хайрлах үедээ л Бурханыг хайрлаж, дараа нь амь зан чанар чинь өөрчлөгдөөгүй хэвээр бол чи харанхуйн нөлөөний бүрхүүлээс зугтаж чадахгүй хэвээр байх бөгөөд Сатанд хүлэгдэж, түүнд мэхлүүлэхээс чөлөөлөгдөж мөн л чадахгүй байх болно. Тийм ямар ч хүн Бурханаар бүрэн авхуулж чадахгүй; эцэст нь тэдний сүнс, сэтгэл, бие Сатанд харьяалагдсан хэвээр байх болно. Үүнд эргэлзэх зүйл үгүй. Бурханаар бүрэн авхуулж чадахгүй тэдгээр хүмүүс өөрсдийн

анхдагч байр луугаа, өөрөөр хэлбэл, Сатан руу буцан очих бөгөөд Бурханаас ирэх шийтгэлийн дараагийн алхмыг хүлээн авахын тулд гал болон хүхэрт нууранд унана. Бурханаар авхуулсан хүмүүс нь Сатаныг орхиж, эзэмшлээс нь зугтсан хүмүүс юм. Тийм хүмүүсийг албан ёсоор хаанчлалын ардын тоонд оруулна. Ингэж л хаанчлалын ард бий болдог билээ. Чи ийм хүн болохыг хүсэж байна уу? Чи Бурханаар авхуулахыг хүсэж байна уу? Чи Сатаны эзэмшлээс зугтаж, Бурханд эргэн очихыг хүсэж байна уу? Чи одоо Сатанд харьяалагдаж байна уу, эсвэл хаанчлалын ардын тоонд орсон уу? Ийм зүйлс нь бүгд тодорхой байх ёстой бөгөөд ямар ч нэмэлт тайлбар шаардлагагүй.

Өнгөрсөн үед, олон хүн итгэл найдвараасаа үүдэн жолоогүй санаархал болон үзлээр эрж хайсан. Эдгээр асуудлыг одоохондоо хойш тавъя; гол зүйл нь та бүхнийг Бурханы өмнө хэвийн нөхцөл байдалтай байлгаж, Сатаны нөлөөллийн дөнгөнөөс аажмаар ангижруулах хэрэгжүүлэлтийн замыг олох явдал, ингэснээр та нар Бурханаар авхуулж, Бурханы та нараас хүссэн зүйлийг газар дээр амьдран харуулж чадах юм. Ийм маягаар л Бурханы санаа зорилгыг биелүүлж чадна. Олон хүн Бурханд итгэдэг боловч Бурханы хүсдэг зүйл юу болохыг, мөн Сатаны хүсдэг зүйл юу болохыг мэддэггүй. Тэд бусдад мунгинуу байдлаар итгэж, зүгээр л урсгал даган явдаг, иймээс хэзээ ч Христэд итгэгчийн хэвийн амьдралтай байдаггүй; үүнээс гадна, тэдэнд Бурхантай харилцах хэвийн харилцаа байх нь бүү хэл, хүн хоорондын ямар ч хэвийн харилцаа байдаггүй. Бурханы хүсэлд саад учруулж чадах хүний хүндрэл бэрхшээл, алдаа дутагдал олон гэдгийг үүнээс харж болно. Хүн Бурханд итгэх зөв замд ороогүй, мөн хүний амьдралын жинхэнэ туршлагад ч ороогүй гэдгийг батлахад энэ нь хангалттай юм. Тэгвэл Бурханд итгэх зөв замд орох гэдэг нь юу гэсэн утгатай вэ? Зөв замд орно гэдэг нь чи Бурханы өмнө зүрх сэтгэлээ үргэлж тайван байлгаж, Бурхантай хэвийн ярилцаж, хүнд дутагдаж байгаа зүйлсийг аажмаар мэдэж, Бурханы талаарх гүнзгий мэдлэгийг алгуур олж авна гэсэн үг юм. Үүгээр дамжуулан чиний сүнс өдөр бүр шинэ ойлголт болон гэгээрлийг олж авдаг; чиний хүсэл эрмэлзэл нэмэгдэж, үнэн рүү орохоор эрэлхийлдэг. Өдөр болгон шинэ гэрэл, шинэ ухаарал байдаг. Энэ замаар дамжуулан чи Сатаны нөлөөллөөс аажмаар ангижирч, амь чинь өсдөг. Ийм хүмүүс зөв замд орчихсон. Өөрийн бодит туршлагаа үнэлж дүгнэн, итгэлдээ эрэлхийлсэн замаа шалга: Дээр дурдсан зүйлстэй эдгээрийг харьцуулаад үзвэл чи зөв замд орсон уу? Ямар зүйлүүд дээр чи Сатаны дөнгө болон нөлөөнөөс ангижирсан бэ? Хэрвээ чи зөв замд хараахан ороогүй бол Сатантай холбогдсон холбоо чинь тасраагүй байна. Ингээд байгаад байвал Бурханыг хайрлахаар эрж хайж байгаа чинь жинхэнэ, үнэнч, ариун хайранд хүргэх болов уу? Бурханы төлөөх чиний хайр бол гуйвшгүй агаад чин сэтгэлийнх гэж чи хэлдэг боловч Сатаны дөнгөнөөс ангижраагүй. Чи Бурханыг хуурахаар оролдож байгаа биш гэж үү? Хэрэв чи Бурханыг гэсэн ариун хайранд хүрч, Бурханаар бүрэн авхуулж, хаанчлалын ардын тоонд орохыг хүсэж байгаа бол эхлээд Бурханд итгэх зөв замд орох ёстой.

БУРХАНЫ АЖЛЫН АЛХМУУДЫН ТУХАЙ

Гаднаа бол Бурханы өнөөгийн ажлын алхмууд аль хэдийн дуусаж, хүн Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, цохилт, цэвэршүүлэлтийг аль эрт туулж, үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт, гэсгээлтийн цаг үеийн цэвэршүүлэлт, үхлийн шалгалт, товойлгогчдийн шалгалт, Бурханыг хайрлах цаг үе гэх мэт алхмыг туулсан мэт харагддаг. Гэхдээ хүмүүс алхам бүрд асар их бэрхшээл туулсан хэр нь Бурханы хүслийг мэдэхгүй хэвээр байдаг. Жишээ нь, үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтыг аваад үз: Тэд өөрсдийн олж авсан зүйл, мэддэг болсон зүйл, Бурханы хүрэхийг хүсдэг үр дүнг одоо ч тодорхой мэддэггүй. Бурханы ажлын хурдыг харахад хүн өнөөгийн хурдыг гүйцэх ямар ч чадваргүй харагддаг. Бурхан ажлынхаа эдгээр алхмыг хүнд эхлээд илчилдэг бөгөөд аль ч алхамд хүний төсөөлөхүйц түвшинд заавал хүрэх гэдэг юм биш, харин үүнээс нэг асуудлыг тодорхойлж байгааг харж болно. Бурхан үнэхээр олж авч болох хүнээ төгс болгохын тулд дээрх бүх алхмыг хэрэгжүүлэх ёстой. Бүлэг хүмүүсийг төгс болгохын тулд Бурхан ямар алхмуудыг хэрэгжүүлэх ёстойг харуулах зорилгоор энэ ажлыг хийдэг. Иймээс гаднаас нь харахад Бурханы ажлын алхмууд гүйцэлдсэн ч мөн чанартаа Бурхан хүн төрөлхтнийг албан ёсоор төгс болгож эхэллээ. Хүмүүс үүнийг тодорхой мэддэг байх ёстой: Бурханы ажлын алхмууд гүйцэлдсэн болохоос ажил өөрөө дуусгавар болоогүй. Гэвч хүмүүс үзэлдээ, Бурханы ажлын алхмууд бүгд хүнд илчлэгдсэн тул Бурханы ажил дууссан гэдэгт огт эргэлзэж болохгүй гэж итгэдэг. Аливааг иймэрхүү маягаар харах нь шал буруу. Бурханы ажил хүний үзэлтэй нийцдэггүй бөгөөд иймэрхүү үзэлд тал бүрээс хариу цохилт өгдөг; ялангуяа Бурханы ажлын алхмууд хүний үзлээс зөрдөг. Энэ бүхэн Бурханы мэргэн ухааныг харуулдаг. Хүний үзэл алхам тутамдаа үймээн үүсгэдгийг харж болох бөгөөд Бурхан хүний төсөөлдөг бүх зүйлд хариу цохилт өгдөг гэдэг нь бодит туршлагын үеэр илэрхий болдог. Хүн бүр Бурханыг дэндүү хурдан ажилладаг, өөрсдийг нь ямар нэг ойлголттой болж амжаагүй, будилуу байдалтай хэвээр байхад Бурханы ажил нэг л мэдэхэд дуусгавар болдог гэж боддог. Бурханы ажлын алхам бүр ийм байдаг. Бурхан хүмүүсээр тоглоом тохуу хийж байна гэж ихэнх хүн итгэдэг ч Бурханы ажлын санаа зорилго тийм биш. Бурхан хивэх арга барилаар ажилладаг: эхлээд морин дэл дээр давхиж явахдаа цэцэгсийг зэрвэсхэн харах мэт байснаа дараа нь нарийн ширийн рүү ордог, тэгээд эдгээр нарийн ширийнийг бүрэн боловсронгуй болгодог—энэ нь хүмүүсийг цочирдуулдаг. Хүмүүс Бурханыг мэхлэхээр оролдон, тодорхой түвшинд хүртэл зүгээр л аргацааж чадах юм бол Бурхан сэтгэл хангалуун болно гэж боддог. Бодит байдал дээр, Бурхан хүний аргацаах оролдлогод сэтгэл ханаж яаж чадах юм бэ? Бурхан дээд зэргийн үр дүнд хүрэхийн тулд хүмүүсийг гэнэдүүлэх, мэдээгүй байхад нь цохилт өгөх байдлаар ажилладаг; ингэх нь хүмүүсийг Бурханы мэргэн ухааны талаар илүү их мэдлэгтэй болгож, Бурханы зөвт байдал, сүр жавхлан, халдашгүй зан чанарыг илүү их ойлгуулдаг.

Өнөөдөр Бурхан хүнийг албан ёсоор төгс болгож эхэллээ. Төгс болгуулахын тулд хүмүүс Бурханы үгийн илчлэл, шүүлт, гэсгээлтийг туулах ёстой бөгөөд Бурханы үгийн шалгалт, цэвэршүүлэлтийг (үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт гэх мэт) туулах ёстой, мөн үхлийн шалгалтыг тэсвэрлэж чаддаг байх ёстой. Тэгэхээр Бурханы шүүлт, гэсгээлт, шалгалт дунд Бурханы хүслийг үнэхээр мөрддөг хүмүүс Бурханыг зүрх сэтгэлийнхээ угаас магтаж чаддаг бөгөөд Бурханыг туйлын дуулгавартай дагаж, өөрсдийгөө орхиж, улмаар чин үнэнч, нэгэн үзүүрт, цэвэр ариун зүрх сэтгэлээр Бурханыг хайрлаж чаддаг; төгс хүн ийм байдаг бөгөөд Бурханы хийхээр зорьдог ажил, Түүний гүйцэлдүүлэх ажил яг энэ мөн. Хүмүүс Бурханы ажилладаг арга барилын талаар яаран дүгнэлт гаргах ёсгүй. Тэд гагцхүү амь руу орохоор эрэлхийлэх ёстой. Ингэх нь үндсэн зүйл. Бурханы ажлын арга барилыг байнга бүү шинж; энэ нь чиний хэтийн ирээдүйд л саад хийнэ. Бурханы ажилладаг арга барилаас чи хэр ихийг харсан бэ? Чи хэр дуулгавартай байсан бэ? Бурханы ажлын арга барил бүрээс чи хэр ихийг олж авсан бэ? Бурханаар төгс болгуулахад чи бэлэн үү? Төгс болгуулахыг хүсэж байна уу? Эдгээр нь бүгд та нарын тодорхой ойлгож, орох ёстой зүйлс юм.

ЯЛЗАРСАН ХҮН БУРХАНЫГ ТӨЛӨӨЛЖ ЧАДАХГҮЙ

Хүн үргэлжид харанхуйн нөлөөний нөмрөг дор, Сатаны нөлөөнд хүлэгдэн, мултарч чадахгүй амьдарч ирсэн бөгөөд түүний зан чанарыг Сатан төлөвшүүлсэн болохоор улам бүр ялзарсаар байдаг. Хүн үргэлж ялзарсан сатанлаг зан чанартаа автан амьдарч, Бурханыг үнэхээр хайрлаж чаддаггүй гэж хэлж болно. Ийм болохоор хэрвээ хүн Бурханыг хайрлахыг хүсвэл өөрийгөө зөвтгөдөг, өөрийгөө өргөмжилдөг, биеэ тоосон, ихэрхүү зан гэх мэт Сатаны зан чанарт харьяалагддаг бүхнээсээ ангижрах ёстой. Эс бөгөөс, түүний хайр бохирдсон, сатанлаг хайр бөгөөд Бурханы сайшаалыг хүртэж яасан ч чадахааргүй хайр юм. Ариун Сүнс шууд төгс болгож, харьцаж, эвдэж, засаж, сахилгажуулж, цохиж, цэвэршүүлэхгүй бол хэн ч Бурханыг жинхэнээсээ хайрлаж чадахгүй. Зан чанарын чинь нэг хэсэг Бурханыг төлөөлдөг, тиймээс өөрийгөө Бурханыг үнэхээр хайрладаг гэж хэлж байгаа бол чи биеэ тоосон яриатай хүн бөгөөд мулгуу нэгэн юм. Ийм хүмүүс бол тэргүүн тэнгэрэлч мөн! Хүний төрөлхийн уг чанар Бурханыг шууд төлөөлж чаддаггүй. Тэр Бурханаар төгс болгуулж төрөлх уг чанараа хаях ёстой бөгөөд зөвхөн Бурханы хүслийг анхаарч, Бурханы санаа зорилгыг биелүүлж, түүнчлэн Ариун Сүнсний ажлыг туулах тэр үед л түүний амьдран харуулдаг зүйлийг Бурхан хүлээн зөвшөөрөх боломжтой. Ариун Сүнсний ашигладаг хүн биш л бол махан биед амьдардаг хэн ч Бурханыг шууд төлөөлж чадахгүй. Гэхдээ, тийм хүний хувьд ч гэсэн зан чанар болон амьдран харуулдаг байдал нь Бурханыг бүрэн төлөөлдөг гэж хэлж болохгүй; түүний амьдран харуулдаг зүйлийг Ариун Сүнс чиглүүлдэг гэж л хэлж болно. Тийм хүний зан чанар Бурханыг төлөөлж чадахгүй.

Хүний зан чанарыг Бурхан тодорхойлдог, энэ нь маргаангүй бөгөөд үүнийг эерэг зүйл гэж үзэж болох боловч, зан чанарыг нь Сатан төлөвшүүлж ирсэн, тиймээс хүний зан чанар бол бүхэлдээ Сатаны зан чанар юм. Бурхан аливааг хийхдээ эрс шулуун зан чанартай байдаг ба ийм зан чанар надад ч бас илэрдэг, би яг адилхан зан ааштай тул миний энэ зан чанар Бурханыг төлөөлдөг гэж зарим хүн хэлдэг. Энэ ямар төрлийн хүн бэ? Ялзарсан сатанлаг зан чанар Бурханыг төлөөлж чадна гэж үү? Өөрийнх нь зан чанар Бурханыг төлөөлдөг гэж хэлдэг хэн ч бай, Бурханыг доромжилж, Ариун Сүнсийг гутааж байна! Ариун Сүнсний ажилладаг арга замаас харвал, газар дээр Бурханы хийдэг ажил нь гагцхүү байлдан дагуулах явдал билээ. Ийм учраас хүнд хараахан цэвэрлээгүй олон завхарсан сатанлаг зан чанар байдаг, хүн Сатаны дүр төрхийг амьдран харуулсаар л байдаг, тэр үүнийгээ сайн зүйл гэж итгэдэг бөгөөд энэ нь хүний махан биеийн үйл хэргийг төлөөлдөг юм. Бүр тодруулбал, энэ нь Сатаныг төлөөлдөг бөгөөд Бурханыг яавч төлөөлж чадахгүй. Хүн тэнгэрийн амьдралыг газар дээр эдэлж, “Өө Бурхан минь! Би Таныг хайрлаж ханахгүй нь” гэх мэт үг хэлж чадах хэмжээнд Бурханыг аль хэдийн хайрладаг, мөн хамгийн өндөр хүрээнд хүрсэн байсан ч гэсэн тэднийг Бурханыг амьдран харуулдаг юм уу Бурханыг төлөөлдөг гэж хэлж болохгүй, учир нь хүний мөн чанар Бурханыхтай адилгүй билээ. Хүн Бурхан болох нь байтугай Бурханыг хэзээ ч амьдран харуулж чадахгүй. Ариун Сүнсний захирамж дор хүний амьдран харуулдаг зүйл Бурханаас хүнд тавьдаг шаардлагын дагуу л байдаг.

Сатаны бүх үйлдэл, үйл хэрэг хүнээс харагддаг. Одоо хүний бүх үйлдэл, үйл хэрэг бол Сатаны илэрхийлэл юм, иймд Бурханыг төлөөлж чадахгүй. Хүн Сатаны биелэл бөгөөд хүний зан чанар Бурханы зан чанарыг төлөөлж чаддаггүй. Зарим хүн сайн зан ааштай байдаг; Бурхан ийм хүний зан аашаар дамжуулан зарим нэг ажил хийж болох ба тэдний хийдэг ажлыг Ариун Сүнс чиглүүлж байдаг. Гэсэн ч түүний зан чанар Бурханыг төлөөлж чадахгүй. Тэдэн дээр Бурханы хийдэг ажил бол ердөө л аль хэдийн дотор нь байгаа зүйл дээр ажиллаж, өргөжүүлэх явдал юм. Өнгөрсөн эрин үеүдийн эш үзүүлэгчид ч бай, Бурханы ашигласан хүмүүс ч бай, хэн ч Бурханыг шууд төлөөлж чадахгүй. Бүх хүн орчин нөхцөлийн эрхээр л Бурханыг хайрлаж эхэлдэг ба хэн ч өөрийн хүслээр хамтран ажиллахаар чармайдаггүй. Эерэг зүйлс гэж юу вэ? Бурханаас шууд ирдэг бүхэн эерэг юм. Гэхдээ хүний зан чанарыг Сатан төлөвшүүлсэн бөгөөд Бурханыг төлөөлж чадахгүй. Зөвхөн бие махбодтой болсон Бурханы хайр, зовлонг тэвчих хүсэл, зөвт байдал, хүлцэнгүй, даруу, нуугдмал байдал л Бурханыг шууд төлөөдөг. Учир нь Тэр ирэх үедээ нүгэлт уг чанаргүй байсан ба Сатаны төлөвшлийг олж авалгүйгээр Бурханаас шууд ирсэн. Есүс зөвхөн нүгэлт бие махбодын төрхтэй болохоос биш нүглийг төлөөлдөггүй; тиймээс цовдлолоор дамжуулан (цовдлолын мөчийг нь оролцуулаад) ажлаа гүйцэлдүүлэхээс өмнөх үеийг хүртэлх Түүний үйлдэл, үйл хэрэг, үг бүгд Бурханыг шууд төлөөлдөг. Нүгэлт уг чанартай ямар ч хүн Бурханыг төлөөлж чадахгүй ба хүний нүгэл Сатаныг төлөөлдөг гэдгийг батлахад Есүсийн жишээ хангалттай юм.

Өөрөөр хэлбэл, нүгэл Бурханыг төлөөлдөггүй, Бурхан бол нүгэлгүй. Хүнд Ариун Сүнсний хийсэн ажлыг ч гэсэн Ариун Сүнс чиглүүлсэн л гэж үзэж болохоос биш Бурханы оронд хүн хийсэн гэж хэлж болохгүй. Гэхдээ, хүний тухайд бол түүний нүгэл ч, зан чанар ч Бурханыг төлөөлдөггүй. Өнгөрсөн үеэс өнөөдрийг хүртэл Ариун Сүнсний хүнд хийсэн ажлаас дүгнэвэл хүний амьдран харуулж байгаа бүхэн нь Ариун Сүнс хүн дээр ажилласны үр дүн гэдэг нь харагдана. Ариун Сүнс харьцаж, сахилгажуулсны дараа тун цөөн хүн үнэнийг амьдран харуулж чаддаг. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнс л ажиллаад байдаг, хүний зүгээс хамтын ажиллагаа байдаггүй. Үүнийг тодорхой харж байна уу? Ийм болохоор Ариун Сүнсийг ажиллаж байхад Түүнтэй бүх чадлаараа хамтран ажиллаж, улмаар үүргээ биелүүлэхийн тулд чи юу хийх ёстой вэ?

ШАШНЫ ҮЙЛЧЛЭЛЭЭС АНГИЖРАХ ЁСТОЙ

Өөрийн ажлыг бүх орчлон ертөнцөд эхлүүлснээс хойш Бурхан нийгмийн бүх давхаргын хүмүүсийг оролцуулаад Өөрт нь үйлчлэх олон хүнийг урьдчилан тогтоосон. Түүний зорилго бол Өөрийн хүслийг биелүүлж, газар дээрх Өөрийн ажлыг төвөггүй гүйцэлдүүлэхэд оршино. Өөрт нь үйлчлэх хүмүүсийг сонгох Бурханы зорилго энэ билээ. Бурханд үйлчилдэг хүн бүр Бурханы хүслийг ойлгох ёстой. Түүний энэхүү ажил Бурханы мэргэн ухаан болон бүхнийг чадагч хүч, газар дээрх Түүний ажлын зарчмыг хүмүүст илүү тодорхой болгодог. Хүмүүс Түүний үйл хэргийг илүү тодорхой мэдээсэй гэсэндээ Өөрийн ажлыг хийж, хүмүүстэй харилцахын тулд үнэндээ Бурхан газар дээр ирсэн. Өнөөдөр, энэ бүлэг хүмүүс та нар бодитой Бурханд үйлчлэх хувьтай билээ. Энэ бол та нарын хувьд тоо томшгүй их ерөөл—Бурхан та нарыг үнэхээр өргөж байгаа хэрэг юм. Өөртөө үйлчлэх хүнийг сонгоход Бурханд үргэлж Өөрийн гэсэн зарчим байдаг. Бурханд үйлчлэх нь хүмүүсийн төсөөлдөг шиг зүгээр нэг урам зоригийн асуудал ердөө ч биш. Бурханы өмнө үйлчилдэг хэн боловч Бурханы удирдамж болон Ариун Сүнсний ажил тэдэнд байгаа учраас, мөн тэд үнэнийг эрэлхийлдэг хүмүүс учраас тийнхүү үйлчилдэг гэдгийг өнөөдөр та нар хардаг. Эдгээр нь Бурханд үйлчилдэг бүх хүнд байх ёстой хамгийн наад захын болзол билээ.

Бурханд үйлчлэх нь тийм ч амархан ажил биш. Ялзарсан зан чанар нь өөрчлөгдөлгүй үлдсэн хүмүүс хэзээ ч Бурханд үйлчилж чадахгүй. Хэрэв чиний зан чанар Бурханы үгээр шүүгдэж, гэсгээгдээгүй бол зан чанар чинь Сатаныг төлөөлсөөр байдаг. Чи “сайн санааныхаа” улмаас Бурханд үйлчилдэг, чиний үйлчлэл сатанлаг уг чанарт чинь үндэслэдэг гэдгийг энэ нь баталдаг. Чи төрөлхийн зан аашаараа, өөрийн хувийн хүсэл зоргын дагуу Бурханд үйлчилдэг. Түүгээр ч барахгүй хийхийг хүсэж байгаа зүйлд чинь Бурхан баярлаж, хийхийг хүсдэггүй зүйлийг чинь Бурхан үзэн яддаг гэж чи үргэлж боддог; чи зөвхөн өөрийн хүсэл

зоргын дагуу л ажилладаг. Үүнийг Бурханд үйлчилж байна гэж хэлж болох уу? Эцсийн эцэст чиний амь зан чанар өчүүхэн төдий ч өөрчлөгдөхгүй; харин ч үйлчлэл чинь чамайг бүр илүү зөрүүд болгосноор завхарсан зан чанарыг чинь туйлын үхширмэл болгоно. Тийм болохоор, Бурханд үйлчлэх талаар зөвхөн өөрийн чинь зан аашинд голлон суурилсан дүрэм журам, зан чанарынхаа дагуу үйлчилдэг үйлчлэлээс чинь урган гарсан туршлага чамд бий болно. Эдгээр нь хүний туршлага болон сургамж юм. Энэ бол хорвоо дээр амьдрах хүний амьдралын гүн ухаан юм. Ийм хүмүүсийг фарисайчууд, шашны албан тушаалтнууд гэж ангилж болно. Хэрвээ тэд хэзээ ч сэрж гэмшихгүй бол эцсийн өдрүүдэд хүмүүсийг хууран мэхэлдэг хуурамч Христүүд, антихристүүд болж хувирах нь гарцаагүй. Яриад байсан хуурамч Христүүд болон антихристүүд ийм хүмүүсийн дундаас гарч ирнэ. Хэрвээ Бурханд үйлчилдэг хүмүүс өөрсдийн зан аашаа дагаж, өөрсдийн хүсэл зоригийн дагуу үйлддэг бол хэзээ ч хамаагүй таягдан хаягдах эрсдэлтэй. Бурханд үйлчилж олж авсан олон жилийн туршлагаа бусдын зүрх сэтгэлийг өөртөө татаж, тэднийг сургамжилж, хянаж, өндөр байр суурийг эзлэхэд ашигладаг хүмүүс—хэзээ ч гэмшиж, хэзээ ч нүглээ улайж, байр суурийн ашиг хонжооноос хэзээ ч татгалздаггүй—энэ хүмүүс Бурханы өмнө унах болно. Тэд бол Паултай адил, дээгүүр зиндаагаараа бардамнаж, эрдэм чадлаа гайхуулдаг. Бурхан ийм хүмүүсийг төгс болгохгүй. Ийм үйлчлэл Бурханы ажилд саад учруулдаг. Хүмүүс үргэлж хуучинтайгаа зууралддаг. Тэд өнгөрсөн үеийн үзэлтэй, өнгөрсөн үеийн бүх зүйлтэй зууралддаг. Энэ нь тэдний үйлчлэлд асар их саад бартаа болдог. Хэрэв чи тэдгээрийг хаяж чадахгүй бол эдгээр зүйл бүхий л амьдралыг чинь үгүй хийх болно. Хэдий чи гүйж байгаад хөлөө хугалж, хөдөлмөрлөж байгаад нуруугаа гэмтээсэн ч гэсэн, бүр Бурханд үйлчлэхэд амиа зориулсан ч гэсэн Бурхан чамайг өчүүхэн төдий ч сайшаахгүй. Харин ч эсрэгээрээ: Тэр чамайг мууг үйлдэгч гэж хэлнэ.

Өнөөдрөөс эхлэн, ямар ч шашны үзэлгүй, өөрсдийн хуучин би-гээ орхиход бэлэн, Бурханыг цайлган сэтгэлээр дуулгавартай дагадаг хүмүүсийг Бурхан албан ёсоор төгс болгож, Бурханы үгийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Тэр төгс болгоно. Энэ хүмүүс өндийн босож Бурханд үйлчлэх ёстой. Бурханд эцэс төгсгөлгүй элбэг дэлбэг байдал, энгүй их мэргэн ухаан байдаг. Түүний гайхалтай ажил, үнэт үгс нь бүр ч олон хүн эдлэхийг хүлээж байгаа. Одоогийн байдлаар, шашны үзэлтэй, дээгүүр зиндаандаа эрддэг, өөрсдийгөө хойш тавьдаггүй хүмүүст эдгээр шинэ зүйлийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдаг. Ариун Сүнс энэ хүмүүсийг төгс болгох боломжгүй юм. Хэрвээ хүн дуулгавартай байхаар шийдээгүй, Бурханы үгээр цангадаггүй бол тэд эдгээр шинэ зүйлийг хүлээн зөвшөөрөх аргагүй байдаг. Тэд зүгээр л улам бүр тэрслүү, улам ов мэхтэй болж, тийнхүү буруу замд орж дуусдаг. Одоо Өөрийн ажлыг хийхдээ Бурхан, Өөрийг нь үнэхээр хайрлаж, шинэ гэрлийг хүлээн зөвшөөрч чадах илүү олон хүнийг өргөж, Тэр дээгүүр зиндаагаараа бардамнадаг шашны албан тушаалтнуудыг бүрмөсөн цавчин унагана. Өөрчлөлтийг зөрүүдлэн эсэргүүцдэг ийм хүмүүсээс нэгийг ч Тэр

хүсдэггүй. Чи энэ хүмүүсийн нэг байхыг хүсэж байна уу? Чи үйлчлэлээ дур зоргоороо гүйцэтгэдэг үү, эсвэл Бурханы шаардсаныг хийдэг үү? Энэ бол чиний өөрөө мэдэж байх ёстой зүйл юм. Чи шашны албан тушаалтан уу, эсвэл Бурханаар төгс болгуулсан дөнгөж мэндэлсэн нярай юу? Чиний үйлчлэлээс хэр ихийг нь Ариун Сүнс сайшаадаг вэ? Үүнээс хэр ихийг нь Бурхан бүр санах ч үгүй вэ? Олон жилийн үйлчлэлийн чинь үр дүнд амь чинь хэр их өөрчлөгдсөн бэ? Чи энэ бүхнийг тодорхой мэдэж байна уу? Хэрвээ чамд жинхэнэ итгэл байдаг бол чи урьдын шашны хуучин үзлээ орхиж, Бурханд шинэ арга замаар илүү сайн үйлчлэх болно. Одоо өндийн босоход тийм ч их оройтоогүй байна. Шашны хуучин үзлийн улмаас хүн бүхий л амьдралаа алдаж болно. Хүний олж авсан туршлага Бурханаас төөрч, аливааг өөрсдийнхөөрөө хийхэд хүргэж болно. Хэрэв чи ийм зүйлийг хаяхгүй бол, амийн өсөлтөд чинь саад тээг болно. Өөрт нь үйлчилдэг хүмүүсийг Бурхан үргэлж төгс болгодог, тэднийг амархан хөөн зайлуулдаггүй. Хэрвээ чи Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг үнэхээр хүлээн зөвшөөрч, шашны хуучин хэрэгжүүлэлт болон дүрэм журмаа хаяж, шашны хуучин үзлээр өнөөдрийн Бурханы үгийг хэмжихээ больж чадсан цагт л чамд ирээдүй байх болно. Хэрвээ чи хуучинтайгаа зууралдаж, тэдгээрийг нандигнасан хэвээр байвал чамд аврагдах ямар ч арга үгүй. Бурхан тийм хүмүүсийг огт тоодоггүй. Хэрвээ чи үнэхээр төгс болгуулахыг хүсэж байгаа бол өмнөх бүх зүйлээ бүрмөсөн орхихоор шийдэх ёстой. Өмнө нь хийгдсэн зүйл зөв байсан ч гэсэн, энэ нь Бурханы ажил байсан ч гэсэн чи үүнийг орхиж, үүнтэй зууралдахаа больж чадах ёстой. Энэ нь гарцаагүй Ариун Сүнсний ажил байгаад Ариун Сүнс шууд хийсэн байсан ч гэсэн өнөөдөр үүнийг орхих ёстой. Үүнтэй зууралдах ёсгүй. Энэ бол Бурханы шаардлага, бүх зүйл шинэчлэгдэх ёстой. Бурхан Өөрийн ажил болон үгэндээ өмнө нь явагдсан хуучин зүйлийг дурддаггүй, Тэрээр хуучин түүхийг ухдаггүй. Бурхан үргэлж шинэ бөгөөд хэзээ ч хуучин байдаггүй Бурхан билээ. Тэр өнгөрсөн үеийн үгтэйгээ ч зууралддаггүй нь Бурхан ямар ч дүрэм журмыг дагадаггүй гэдгийг харуулдаг. Бурхан өмнө нь хийж байсан арга барилаар ажиллахаа больсон байхад хүн болохын хувьд, чи өнгөрсөн үеийн зүйлстэй үргэлж зууралдаж, тэдгээрийг тавьж явуулахаас татгалзаж, тэдгээрийг улиг болсон байдлаар тууштай хэрэгжүүлдэг бол үг болон үйлдэл чинь балагтай бус уу? Чи Бурхантай дайсагнаж байгаа бус уу? Чи энэ хуучин зүйлсээс болж бүхий л амьдралаа сүйтгэж, үрэн таран хийхийг хүсэж байна уу? Эдгээр хуучин зүйл чамайг Бурханы ажилд саад учруулдаг нэгэн болгох болно. Чи ийм хүн болмоор байна уу? Хэрэв чи тэгэхийг үнэхээр хүсэхгүй байвал хийж байгаа зүйлээ даруй зогсоогоод бүгдийг өөрчил; бүхнийг дахин шинээр эхэл. Бурхан өнгөрсөн үйлчлэлийг чинь санахгүй.

БУРХАНД ИТГЭХДЭЭ БУРХАНЫГ ДУУЛГАВАРТАЙ ДАГАХ ЁСТОЙ

Чи яагаад Бурханд итгэдэг вэ? Ихэнх хүн энэ асуултад будилдаг. Тэд үргэлж, бодитой Бурхан, тэнгэр дэх Бурхан хоёрын талаар тэс ондоо хоёр үзэл бодолтой байдаг нь тэд дуулгавартай дагахын тулд биш, харин тодорхой ашиг тус хүртэхийн тулд, эсвэл гай гамшгаас үүдсэн зовлонгоос мултрах гэж Бурханд итгэдэг гэдгийг харуулдаг. Тэр үед л тэд бага зэрэг дуулгавартай байдаг боловч дуулгавартай байдал нь болзолтой, хэтийн ирээдүйнхээ төлөө, албан хүчээр хийдэг. Тэгэхээр чи яг яагаад Бурханд итгэдэг юм бэ? Хэрвээ энэ нь гагцхүү хэтийн ирээдүй, хувь заяаны чинь төлөө юм бол огт итгэхгүй байсан нь дээр. Иймэрхүү итгэл бол өөрийгөө хуурч, өөрийгөө тайтгаруулж, өөрийгөө биширч буй хэрэг юм. Хэрвээ итгэл чинь Бурханыг дуулгавартай дагах суурин дээр үндэслээгүй бол эцсийн эцэст Бурханд тэрсэлснийхээ төлөө чи шийтгүүлэх болно. Итгэхдээ Бурханд дуулгавартай байхыг эрэлхийлдэггүй бүх хүн Бурханд тэрсэлдэг. Бурхан хүмүүсийг Өөрийг нь дуулгавартай дагадаг болоосой гэсэндээ үнэнийг эрж хайж, Өөрийнх нь үгээр цангаж, Өөрийнх нь үгийг идэж ууж, хэрэгжүүлэхийг тэднээс шаарддаг. Санаа зорилго чинь үнэхээр ийм бол Бурхан гарцаагүй чамайг өргөж, чамд нигүүлсэнгүй хандах нь лавтай. Энэ бол маргаангүй бөгөөд үүнийг өөрчлөхийн аргагүй билээ. Хэрвээ санаа зорилго чинь Бурханд дуулгавартай байхын тулд биш өөр зорилготой байдаг бол хэлж, хийдэг бүхэн чинь—Бурханы өмнө залбирах залбирал хийгээд үйлдэл бүр чинь хүртэл—Бурханы эсрэг байх болно. Чи зөөлөн дуутай, эелдэг зан ааштай байж болно, үйлдэл, илэрхийлэл бүр чинь зөв мэт, өөрөө чи дуулгавартай нэгэн шиг харагдаж болох ч санаа зорилго, Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлын чинь тухайд гэвэл чиний хийдэг бүхэн Бурханы эсрэг, ёрын муу байдаг. Хонь шиг дуулгавартай харагддаг атлаа зүрх сэтгэлдээ муу санаа тээж явдаг хүмүүс хонины арьс нөмөрсөн чоно бөгөөд Бурханд шууд халддаг тэднээс Бурхан ганцыг нь ч өршөөхгүй. Ариун Сүнс тэднийг нэг бүрчлэн илчилж, хоёр нүүртэн болгоныг Ариун Сүнс гарцаагүй жигшин голох болно гэдгээ бүх хүнд харуулна. Санаа бүү зов, Бурхан тэдэнтэй нэг бүрчлэн харьцаж, ээлж дараалан зайлуулна.

Хэрвээ чи Бурханы шинэ гэрлийг хүлээн авч чаддаггүй, Бурханы өнөөдөр хийдэг бүхнийг ойлгож чаддаггүй, мөн үүнийг эрж хайдаггүй эсвэл үүнд эргэлзэж, шүүмжилж, үүнийг шинжиж, шинжилдэг бол чамд Бурханыг дуулгавартай дагах сэтгэл гэж алга. Өнөө цагийн гэрэл гарч ирэх үед өчигдрийн гэрлийг нандигнасан хэвээр байж, Бурханы шинэ ажлыг эсэргүүцвэл чи хөгийн амьтнаас цаашгүй бөгөөд Бурханд зориуд тэрсэлдэг хүмүүсийн нэг мөн. Бурханд дуулгавартай байхын гол түлхүүр бол шинэ гэрлийг ойлгож, хүлээн авч, хэрэгжүүлэх чадвартай байх явдал билээ. Энэ л жинхэнэ дуулгавартай байдал юм. Бурханыг хүсэмжлэх хүсэлгүй хүмүүс зориуд Бурханд захирагдаж чаддаггүй, харин байгаа байдалдаа сэтгэл хангалуун байдгаасаа болж Бурханд тэрсэлж л чадна. Хүн өмнө нь ирсэн зүйлд

автсан учраас Бурханыг дуулгавартай дагаж чаддаггүй. Урьд өмнө нь ирсэн зүйлс хүмүүст Бурханы талаарх бүх төрлийн үзэл, төсөөлөл өгч, эдгээр нь тэдний оюун ухаанд Бурханы дүр болсон байдаг. Тиймээс тэд өөрсдийн үзэл болон төсөөлсөн стандартууддаа итгэдэг. Хэрвээ чи, өнөөдөр бодит ажил хийдэг Бурханыг өөрийн төсөөллийн Бурхантай харьцуулдаг бол итгэл чинь Сатанаас гардгийн дээр чиний эрхэмлэдэг зүйлсээр сэвтсэн байна—харин Бурхан ийм итгэлийг хүсдэггүй. Чадвар чансаа нь хэчнээн сүртэй, хэчнээн их зориулдаг нь хамаагүй—бүр бүх насныхаа хичээл зүтгэлийг Түүний ажилд зориулж, зовж тарчилсан ч бай—Бурхан ийм итгэлтэй хэнийг ч сайшаадаггүй. Тэр тэдэнд ердөө л өчүүхэн бага нигүүлсэл хайрлаж, үүнийг хэсэгхэн хугацаанд эдлэх боломж олгодог. Ийм хүмүүс үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг, Ариун Сүнс тэдний дотор ажилладаггүй бөгөөд Бурхан тэднийг ээлж дараалан таягдан хаяна. Хөгшин, залуу байхаас үл хамааран, Бурханд итгэхдээ Бурханыг дуулгавартай дагадаггүй, буруу санаа бодолтой хүмүүс бол эсэргүүцэж, саад хийдэг хүмүүс бөгөөд Бурханд таягдуулан хаягдах нь дамжиггүй. Бурханд огт дуулгавартай байдаггүй, нэрийг нь хүлээн зөвшөөрөх төдий байдаг, Бурханы сайхан сэтгэл, хайр татам байдлыг бага зэрэг мэдэрдэг ч Ариун Сүнсний алхаатай хөл нийлэн алхдаггүй, Ариун Сүнсний одоогийн ажил, үгийг дуулгавартай дагадаггүй хүмүүс Бурханы нигүүлсэл дунд амьдардаг бөгөөд Бурханаар авхуулж, төгс болгуулахгүй. Бурхан дуулгавартай байдал, Бурханы үгийг идэж, ууж, таашааж байгаагаар нь, мөн амьдралынх нь зовлон шаналал, цэвэршүүлэлтээр дамжуулан хүмүүсийг төгс болгодог. Ийм итгэлээр л хүмүүсийн зан чанар өөрчлөгдөж, ингэснээр л тэд Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг эзэмшиж чаддаг. Ухамсартайгаар Бурханыг дуулгавартай дагана гэдэг бол Бурханы нигүүлсэл дунд амьдрахдаа сэтгэл ханалгүй үнэнийг идэвхтэйгээр хүсэмжилж, үнэнийг хайж, Бурханаар авхуулахыг эрэлхийлнэ гэсэн үг; Бурханы ийм л итгэлийг хүсдэг билээ. Бурханы нигүүлслийг эдлэхээс өөр юу ч хийдэггүй хүмүүс төгс болгуулж, өөрчлөгдөж чадахгүй бөгөөд тэдний дуулгавартай байдал, сүсэг бишрэл, хайр, тэвчээр бүгд өнгөцхөн юм. Бурханы нигүүлслийг л эдэлдэг хүмүүс Бурханыг үнэхээр таньж мэдэж чаддаггүй бөгөөд Бурханыг мэдлээ ч мэдлэг нь өнгөцхөн байдгийн дээр “Бурхан хүнд хайртай”, “Бурхан хүнд энэрэнгүй ханддаг” гэх мэт зүйл ярьдаг. Энэ нь хүний амийг төлөөлдөггүй, бас хүмүүс Бурханыг үнэхээр мэддэг гэдгийг харуулдаггүй. Бурханы үг өөрсдийг нь цэвэршүүлж, Бурханы шалгалт өөрсдөд нь ирэх үед хүмүүс Бурханыг дуулгавартай дагаж чадалгүй, харин ч эргэлзэж, бүтэлгүйтдэг бол тэд огтхон ч дуулгаваргүй юм. Тэдэнд Бурханд итгэх итгэлийн талаарх олон дүрэм, хязгаарлалт, мөн олон жилийн итгэлийн дүнд олж авсан хуучин туршлагууд, Библи дээр үндэслэсэн янз бүрийн дүрэм журам байдаг. Иймэрхүү хүмүүс Бурханд дуулгавартай байж чадах уу? Хүмүүний зүйлс дүүрэн энэ хүмүүс яаж Бурханд дуулгавартай байж чадах юм бэ? Тэд эрхэмлэдэг зүйлийнхээ дагуу “дуулгавартай дагадаг”—иймэрхүү дуулгавартай байдлыг Бурхан хүснэ гэж үү? Энэ бол Бурханыг дуулгавартай дагаж байгаа биш,

харин дүрэм журмыг мөрдөж буй хэрэг; мөн өөрсдийгөө тайтгаруулж, сэтгэл хангалуун болгож байгаа явдал юм. Үүнийгээ чи Бурханд дуулгавартай байна гэж хэлбэл Түүнийг доромжилж байгаа хэрэг бус уу? Чи бол мууг үйлддэг, Бурханд тэрслэх ажил онцгойлон хийдэг Египетийн Фараон—Чамайг иймэрхүү үйлчлэл хийхийг Бурхан хүснэ гэж үү? Чи даруйхан гэмшиж, өөрийгөө бага ч гэсэн мэдэх гэж оролдсон нь дээр. Ингэж чадахгүй бол гэртээ харьсан чинь дээр; ингэсэн нь дүр үзүүлж Бурханд үйлчлэл хийснээс чинь хавьгүй дээр. Чи саад болж, үймүүлэхгүй; байр сууриа мэдэж, сайн сайхан амьдарна—ингэсэн нь дээр биш гэж үү? Бас чи Бурханд тэрсэлсэн гэж шийтгүүлэхгүй!

БУРХАНТАЙ ХЭВИЙН ХАРИЛЦАА ТОГТООХ НЬ МАШ ЧУХАЛ

Хүмүүс Бурханд итгэж, хайрлаж, Бурханыг сэтгэл хангалуун байлгах үедээ зүрх сэтгэлээрээ Бурханы Сүнсэнд хүрч, тэгснээрээ Бурханы сэтгэл ханамжийг олж авдаг, мөн зүрх сэтгэлээ ашиглан Бурханы үгтэй холбогдож, улмаар Бурханы Сүнсээр сэтгэлээ хөдөлгүүлдэг. Хэрвээ чи хэвийн сүнслэг амьдралаар амьдарч, Бурхантай хэвийн харилцаа тогтоохыг хүсэж байгаа бол эхлээд зүрх сэтгэлээ Түүнд өгөх ёстой. Түүний өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж, зүрх сэтгэлээ бүхэлд нь Түүнд зориулсны дараа л чи аажмаар хэвийн сүнслэг амьдралтай болж чадна. Хэрвээ хүмүүс Бурханд итгэхдээ зүрх сэтгэлээ Бурханд өгдөггүй, зүрх сэтгэл нь Бурхантай хамт байдаггүй, Бурханы ачааг өөрийн мэт үздэггүй бол хийдэг бүхэн нь Бурханыг хууран мэхлэх үйл, шашны хүмүүсийн ердийн үйл бөгөөд Бурханы сайшаалыг хүртэхгүй. Бурхан ийм хүнээс юу ч олж авч чадахгүй, тэд Бурханы ажилд товойлгогч болон үйлчилж л чадна. Энэ хүмүүс бол Бурханы гэр дэх чимэглэл—орон тоо дүүргэгч, хог новш бөгөөд Бурхан тэднийг ашигладаггүй. Тэдэн дээр Ариун Сүнс ажиллах боломж байдаггүй төдийгүй, төгс болгуулах үнэ цэн ч тэдэнд байдаггүй. Ийм хүн бол жинхэнэ алхаж яваа үхдэл юм. Тэдэнд Ариун Сүнсний ашиглаж болох юу ч байдаггүй—тэднийг Сатан бүрэн эзэмдэж, гүн гүнзгий завхруулсан. Бурхан энэ хүмүүсийг таягдан хаяна. Ариун Сүнс өнөөдөр хүмүүсийг ашиглахдаа аливааг хийхийн тулд хүмүүсийн хүсүүштэй талуудыг ашиглаад зогсохгүй, мөн хүсэмгүй хэсгүүдийг нь ч төгс болгож, өөрчилдөг. Хэрвээ чи зүрх сэтгэлээ Бурханд цутгаж, Бурханы өмнө тайван байж чаддаг бол чи Ариун Сүнсэнд ашиглуулж, Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авах боломжтой, эрхтэй байх болно. Үүнээс ч илүүтэйгээр Ариун Сүнс дутагдлыг чинь нөхөх боломж чамд гарч ирнэ. Зүрх сэтгэлээ Бурханд өгөх үедээ чи эерэг талдаа илүү гүн гүнзгий оролтод хүрч, мэдлэг ухааны илүү өндөр түвшинд хүрч чадна. Сөрөг талдаа чи өөрийн алдаа, дутагдлыг илүү сайн ойлгож, Бурханы хүслийг хангахаар илүү их эрмэлзэж, эрж хайна. Түүнчлэн чи идэвхгүй байхгүй, харин идэвхтэйгээр орж

чадна. Энэ нь зөв хүн гэдгийг чинь харуулдаг. Зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байж чадна гэж үзвэл, Ариун Сүнснээс магтаал хүлээн авах болон Бурханд таалагдах эсэх чинь идэвхтэйгээр орж чадах уу, үгүй юү гэдгээс чинь ихээхэн хамаарна. Ариун Сүнс хүмүүсийг гэгээрүүлж, ашиглах үедээ тэднийг хэзээ ч идэвхгүй болгодоггүй, харин үргэлж идэвхтэйгээр ахин дэвшихэд хүргэдэг. Ингэх үед хүмүүст сул талууд байсаар байдаг ч тэд сул талдаа үндэслэн амьдардаггүй. Тэд амийн өсөлтөө саатуулалгүй, Бурханы хүслийг хангахаар эрж хайсаар байдаг. Энэ бол стандарт юм. Хэрвээ чи үүнд хүрч чадах юм бол Ариун Сүнсний өмнө байх болсон гэдгийг чинь энэ нь нотолно. Хэрвээ хүн үргэлж сөрөг байдаг бол, мөн гэгээрэл хүлээн авч, өөрийгөө мэдэж авсны дараа ч сөрөг, идэвхгүй хэвээр үлдээд, өндийн босож, Бурхантай хамт ажиллаж чаддаггүй бол тэр хүн Бурханы нигүүлслийг л хүлээн авсан бөгөөд Ариун Сүнс түүнтэй хамт байдаггүй. Тэр хүн сөрөг байна гэдэг нь түүний зүрх сэтгэл Бурхан руу эргээгүй, түүний сүнсийг Бурханы Сүнс хөдөлгөөгүй гэсэн үг юм. Үүнийг бүгд ойлгох ёстой.

Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгах нь хамгийн чухал гэдгийг туршлагаас харж болно. Энэ нь хүмүүсийн сүнслэг амьдрал болон амийн өсөлтийн асуудалтай холбоотой. Зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байвал үнэн болон зан чанарын өөрчлөлтийн төлөөх эрэл хайгуул чинь үр дүнгээ өгнө. Учир нь чи ачаа үүрч Бурханы өмнө ирсэн, маш олон талаар дутуу дулимаг гэдгээ үргэлж мэдэрдэг, чиний мэдэх хэрэгтэй олон үнэн, туулах хэрэгтэй асар их бодит байдал байдаг, мөн Бурханы хүслийг бодолцон үзэх ёстой гэдгийг үргэлж мэдэрдэг. Эдгээр зүйл үргэлж оюун ухаанд чинь байж, чамайг амьсгалж чадахааргүй болтол дээрээс чинь дарж байгаа мэт байдаг, тиймээс зүрх сэтгэлд чинь хүнд оргидог (гэхдээ чи сөрөг байдалд байдаггүй). Ийм хүн л Бурханы үгийн гэгээрлийг хүлээн авч, Бурханы Сүнсээр хөдөлгөгдөх эрхтэй. Өөрийнхөө ачаанаас болж, сэтгэлийн хүнд байдлаасаа болж, мөн Бурханы өмнө төлсөн төлөөс, туулсан зовлонгоосоо болж тэд Бурханы гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авдаг гэж хэлж болно. Учир нь Бурхан хэнийг ч алагчилж үздэггүй. Тэр хүмүүст хандахдаа үргэлж шударга байдаг боловч бас хүмүүст дур зоргоороо, эсвэл болзолгүйгээр өгдөггүй. Энэ бол Түүний зөвт зан чанарын нэг тал юм. Бодит амьдрал дээр ихэнх хүмүүс энэ хүрээнд хараахан хүрээгүй. Ядаж л тэдний зүрх сэтгэл Бурханд хараахан бүрэн хандаагүй учраас амь зан чанарт нь ямар ч томоохон өөрчлөлт гараагүй хэвээр байдаг. Яагаад гэвэл, тэд зөвхөн Бурханы нигүүлсэл дунд амьдардаг ба Ариун Сүнсний ажлыг хараахан олж аваагүй. Бурханаар ашиглуулахын тулд хүмүүсийн хүрэх ёстой шалгуур энэ: Тэдний зүрх сэтгэл Бурханд хандах ёстой, тэд Бурханы үгийн ачааг үүрэх ёстой, хүсэн тэмүүлсэн зүрх сэтгэлтэй байх ёстой, үнэнийг эрж хайхаар шийдсэн байх ёстой. Энэ хүмүүс л Ариун Сүнсний ажлыг олж авч, гэгээрэл, гэрэлтүүлэлтийг нь удаа дараа олж авч чадна. Бурханы ашигладаг хүмүүс гаднаа эрүүл ухаангүй мэт, бусадтай хэвийн харилцаагүй мэт харагддаг боловч тэд ёс зүйтэй ярьдаг, хайхрамжгүй ярьдаггүй бөгөөд зүрх сэтгэлээ Бурханы өмнө үргэлж тайван байлгаж

чаддаг. Яг ийм хүн л Ариун Сүнсээр ашиглагдахад зохистой. Бурханы ярьдаг “эрүүл ухаангүй” энэ хүмүүс бусадтай хэвийн харилцаагүй мэт харагддаг бөгөөд гадаад талын хайр юм уу гаднах дадлыг анхаардаггүй боловч сүнслэг хэрэг явдлын талаар нөхөрлөх үедээ зүрх сэтгэлээ нээж, Бурханы өмнө бодит туршлагаараа олж авсан гэгээрэл, гэрэлтүүлэлтээрээ бусдыг харамгүй хангаж чаддаг. Ингэж тэд Бурханыг гэх хайраа илэрхийлж, Бурханы хүслийг хангадаг. Бусад хүмүүс бүгд тэднийг дооглож, гүтгэж байхад тэд гаднын хүмүүс, хэрэг явдал эсвэл зүйлсийн нөлөөнд автахаас зайлсхийж, Бурханы өмнө тайван байж чаддаг. Тэд өөрийн гэсэн өвөрмөц мэргэн ухаантай мэт санагддаг. Бусад хүн юу хийхээс үл хамааран тэдний зүрх сэтгэл Бурханыг хэзээ ч орхидоггүй. Бусад нь ярилцаж, инээлдэж байхад тэдний зүрх сэтгэл Бурханы өмнө үлдэж, Бурханы үгийг тунгаан бодож, эсвэл зүрх сэтгэлдээ чимээгүйхэн Бурханд залбирч, Бурханы санаа зорилгыг эрж хайж байдаг. Энэ хүмүүс бусадтай хэвийн харилцаатай байхад ач холбогдол өгдөггүй бөгөөд амьдралын гүн ухаангүй юм шиг санагддаг. Тэд цовоо сэргэлэн, хайр татам, гэнэн харагддаг ч бас аядуу тайван байдаг. Энэ бол Бурханы ашигладаг хүний төрх билээ. Амьдралын гүн ухаан, эсвэл “хэвийн эрүүл ухаан” гэх мэтийн зүйлс ийм хүнд ердөө нэмэргүй. Тэд хамаг зүрх сэтгэлээ Бурханы үгэнд зориулсан бөгөөд зүрх сэтгэлд нь Бурхан л байгаа мэт санагддаг. Энэ бол Бурханы “эрүүл ухаангүй” гэж хэлдэг хүн бөгөөд яг ийм хүнийг Бурхан ашигладаг. Бурханы ашигладаг хүний шинж тэмдэг бол: Хэзээ, эсвэл хаана байх нь хамаагүй түүний зүрх сэтгэл үргэлж Бурханы өмнө байдаг бөгөөд бусад хүмүүс хэчнээн завхайрч, шунал тачаал, махан биеэ хэр их өөгшүүлэх нь хамаагүй, энэ хүний зүрх сэтгэл Бурханыг хэзээ ч орхидоггүй, олон нийтийг дагадаггүй. Ийм төрлийн хүн л Бурханаар ашиглагдахад тохирдог бөгөөд энэ төрлийн хүнийг л Ариун Сүнс төгс болгодог. Хэрвээ чи үүнд хүрч чадахгүй бол Бурханаар авхуулж, Ариун Сүнсээр төгс болгуулахад тохирохгүй.

Хэрвээ чи Бурхантай хэвийн харилцаа тогтоохыг хүсвэл зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэх ёстой; энэ суурин дээр чи бусад хүмүүстэй ч хэвийн харилцаатай байх болно. Хэрвээ чи Бурхантай хэвийн харилцаагүй бол бусад хүмүүстэй харилцах харилцаагаа хадгалахын тулд юу ч хийсэн, хэчнээн шаргуу ажиллаж, эсвэл хэчнээн их эрч хүч гаргасан ч бай, энэ нь бүгд хүний амьдралын гүн ухаанд хамаарна. Чи Бурханы үгийн дагуу хүмүүстэй хэвийн харилцаа тогтоохын оронд хүний үзэл бодол, хүний гүн ухаанаар дамжуулан хүмүүсийн дундах байр сууриа хадгалж, бусдаар магтуулж байх болно. Хэрвээ чи хүмүүстэй харилцах харилцаандаа анхаардаггүй, харин Бурхантай хэвийн харилцаатай байж, зүрх сэтгэлээ Бурханд өгч, Түүнд дуулгавартай байж сурахыг хүсдэг бол хүмүүстэй харилцах харилцаа чинь аяндаа хэвийн болно. Тэгвэл энэ харилцаа нь махан бие бус, харин Бурханы хайрын суурин дээр тогтдог. Бусад хүнтэй харилцах махан биеийн харилцаа чамд бараг байдаггүй ч сүнслэг түвшинд бол та нарын хооронд нөхөрлөл, харилцан хайр, тайтгарал, хангалт байдаг. Энэ бүхэн нь Бурханыг сэтгэл хангалуун байлгах хүслийн суурин дээр хийгддэг—эдгээр харилцааг хүний

амьдралын гүн ухаанд тулгуурлан хадгалдаггүй, харин энэ нь Бурханы төлөө ачаа үүрэх үед аяндаа бий болдог. Энэ харилцаа нь чамаас аливаа хиймэл, хүний хүчин чармайлтыг шаарддаггүй, чи гагцхүү Бурханы үгийн зарчмын дагуу л хэрэгжүүлэх хэрэгтэй. Чи Бурханы хүслийг бодолцон үзэхэд бэлэн үү? Бурханы өмнө “эрүүл ухаангүй” хүн байхад бэлэн үү? Чи Бурханд зүрх сэтгэлээ бүрмөсөн өгч, бусад хүмүүсийн дундах байр сууриа үл тоомсорлоход бэлэн үү? Харилцдаг бүх хүнийхээ дундаас чи хэн хэнтэй нь хамгийн сайн харилцаатай байдаг вэ? Хэнтэй нь хамгийн муу харилцаатай байдаг вэ? Хүмүүстэй харилцах харилцаа чинь хэвийн үү? Чи бүх хүнд эн тэнцүү ханддаг уу? Чи амьдралын гүн ухааныхаа дагуу бусадтай харилцах харилцаагаа хадгалдаг уу, эсвэл Бурханы хайрын суурин дээр харилцаа тогтоосон уу? Хүмүүс зүрх сэтгэлээ Бурханд өгөөгүй бол сүнс нь үлбэгэр, хөшүүн, мэдрэмжгүй болдог. Ийм хүмүүс Бурханы үгийг хэзээ ч ойлгохгүй, Бурхантай хэзээ ч хэвийн харилцаатай байж чадахгүй, зан чанар нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Зан чанараа өөрчлөх гэдэг нь зүрх сэтгэлээ Бурханд бүрэн өгч, Бурханы үгээс гэгээрэл, гэрэлтүүлэлт хүлээн авах үйл явц юм. Бурханы ажил нь хүмүүст идэвхтэйгээр орох боломж олгодог, мөн сөрөг талуудаа мэдсэнийхээ дараа тэдгээрээс ангижрах боломж олгодог. Чи Бурханд зүрх сэтгэлээ өгөх үедээ сүснийхээ нарийн хөдөлгөөн бүрийг мэдэрч чадах бөгөөд Бурханы гэгээрэл, гэрэлтүүлэлтийн хэсэг бүрийг мэдэх болно. Чи үргэлжлүүлсээр байх юм бол Ариун Сүнсээр төгс болгуулах замд аажмаар орно. Зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байх тусам сүнс чинь төдий чинээ мэдрэмтгий, нарийн нямбай байж, Ариун Сүнс хэрхэн хөдөлгөдгийг илүү их ухамсарлаж чадна, тэгээд Бурхантай харилцах харилцаа чинь төдий чинээ хэвийн байх болно. Хүмүүсийн хоорондох хэвийн харилцаа нь Бурханд зүрх сэтгэлээ хандуулах суурин дээр тогтдог болохоос хүний хүчин чармайлтаас бий болдоггүй. Хүний зүрх сэтгэлд Бурхан байхгүй бол бусадтай харилцах харилцаа нь ердөө махан биеийн харилцаа юм. Тэдгээр нь хэвийн бус, харин ч хүсэл тачаалд автсан, Бурханы үзэн ядаж, зэвүүцдэг харилцаа юм. Хэрвээ чи сүнс чинь хөдөлгөгдсөн гэж хэлдэг боловч өөртөө таалагддаг, өөрийнхөө хүндэлдэг хүмүүстэй л нөхөрлөхөд бэлэн байж, таалагддаггүй хүмүүс чинь чамтай ярилцахаар ирэхэд өрөөсгөл хандаж, ярихаас татгалздаг бол сэтгэл хөдлөлдөө автдаг, Бурхантай ямар ч хэвийн харилцаагүй гэдгийг чинь энэ нь бүр ч их нотолно. Чи Бурханыг мэхэлж, муу муухайгаа нуун далдлахаар оролдож байгааг энэ нь харуулдаг. Чи зарим мэдлэгээ хуваалцаж чаддаг ч гэсэн буруу санаа зорилго өвөрлөдөг бол хийдэг бүхэн чинь хүний стандартаар л сайн байх бөгөөд Бурхан чамайг магтахгүй. Чи Бурханы ачааны дагуу бус, махан биеийн дагуу үйлдэж байна. Чи Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж, Бурханыг хайрладаг хүн бүхэнтэй хэвийн харилцаатай байж чадвал л Бурханаар ашиглагдахад тохирно. Ингэж чаддаг бол чи бусадтай яаж ч харилцсан бай, амьдралын гүн ухааны дагуу үйлдэхгүй, харин Бурханы ачааг хайхарч, Бурханы өмнө амьдарна. Та нарын дунд ийм хүн хэчнээн байдаг вэ? Бусадтай харилцах харилцаа чинь үнэхээр хэвийн үү?

Энэ нь юун дээр үндэслэдэг вэ? Чиний дотор амьдралын гүн ухаан хэр их байдаг вэ? Чи тэдгээрийг хаясан уу? Хэрвээ зүрх сэтгэл чинь Бурханд бүрэн хандаж чадахгүй бол чи Бурханых биш—чи Сатанаас ирсэн бөгөөд эцэстээ мөн л Сатан руу буцаж очно. Чи Бурханы ардуудын нэг байхад тохирохгүй. Чи эдгээр зүйлийг анхааралтай шалгах ёстой.

ХЭВИЙН СҮНСЛЭГ АМЬДРАЛ ХҮНИЙГ ЗӨВ ЗАМ РУУ ХӨТӨЛДӨГ

Та нар Бурханд итгэгчийн замын өчүүхэн хэсгээр л алхсан ба зөв замд хараахан ороогүй тул Бурханы стандартад хүрэхээс хол хэвээр л байна. Яг одоо та нарын биеийн хэмжээ Бурханы шаардлагад нийцэхэд хангалттай бус. Хэв чанар, завхарсан уг чанараасаа болоод та нар Бурханы ажилд үргэлж хайхрамжгүй ханддаг; үүнд нухацтай ханддаггүй. Энэ нь та нарын хамгийн том дутагдал юм. Ариун Сүнсний алхдаг замыг тодорхойлж чадах нэг ч хүн байхгүй нь гарцаагүй; та нарын ихэнх нь үүнийг ойлгож, тодорхой харж чаддаггүй. Түүнчлэн, та нарын ихэнх нь энэ асуудалд анхаарал хандуулдаггүй, тэр ч бүү хэл, үүнийг үнэн сэтгэлээсээ авч үздэггүй. Та нар энэ хэвээр байж, Ариун Сүнсний ажлыг мэдэхгүй амьдарсаар байвал Бурханд итгэгчийн хувиар явдаг зам чинь хий дэмий байх болно. Учир нь та нар Бурханы хүслийг биелүүлэхээр эрэлхийлэхийн тулд чадах бүхнээ хийдэггүй, мөн Бурхантай сайн хамтран ажилладаггүй. Бурхан та нар дээр ажиллаагүй юм биш, эсвэл Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөөгүй юм биш. Маш хайхрамжгүй болохоороо л чи Ариун Сүнсний ажлыг нухацтайгаар авч үздэггүй. Чи энэ нөхцөл байдлыг даруйхан эргүүлж, Ариун Сүнс хүмүүсийг удирдан хөтөлдөг замаар алхах ёстой. Энэ бол өнөөдрийн гол сэдэв билээ. “Ариун Сүнсний удирдан хөтөлдөг зам” гэдэг нь сүнсээрээ гэгээрэл олж авах; Бурханы үгийг мэддэг болох; урдах замаа тодорхой мэддэг болох; алхам алхмаар үнэнд орох чадвартай байх; Бурханы тухай илүү их мэддэг болохыг хэлдэг. Ариун Сүнс хүмүүсийг удирдан хөтөлдөг зам нь үндсэндээ гажуудал, эндүүрэлгүйгээр Бурханы үгийг илүү тодорхой ойлгох зам бөгөөд тэрхүү замаар явагсад шулуухан алхдаг. Ингэхийн тулд та нар Бурхантай зохицон ажиллаж, хэрэгжүүлэх зөв замыг олж, Ариун Сүнсний удирдан хөтөлдөг замаар алхах хэрэгтэй болно. Энэ нь хүний хамтын ажиллагаатай хамаатай: өөрөөр хэлбэл, Бурханы шаардлагад нийцэхийн тулд та нар юу хийх ёстой, мөн Бурханд итгэх зөв замд орохын тулд хэрхэн авирлах ёстой вэ гэдэг юм.

Ариун Сүнсний удирдан хөтөлдөг замд хөл тавих нь төвөгтэй санагдаж болох ч хэрэгжүүлэлтийн зам чамд тодорхой болох үед энэ нь хавьгүй энгийн санагдах болно. Үнэндээ, хүмүүс Бурханы шаарддаг бүхнийг биелүүлэх чадвартай бөгөөд Бурхан зангууны ноос түүж, эсгий хийхээр оролдож байгаа хэрэг биш юм. Бүхий л нөхцөл байдалд Бурхан хүмүүсийн асуудлыг шийдвэрлэж, санаа зовнилыг нь

арилгахаар эрэлхийлдэг. Та нар бүгд үүнийг ойлгох ёстой; Бурханыг бүү буруугаар ойлго. Хүмүүс Ариун Сүнсний алхдаг замаар Бурханы үгийн дагуу удирдуулдаг. Өмнө дурдсанчлан, та нар зүрх сэтгэлээ Бурханд өгөх ёстой. Энэ нь Ариун Сүнсний удирдан хөтөлдөг замаар явахын урьдач нөхцөл юм. Зөв замд орохын тулд ингэх ёстой. Бурханд зүрх сэтгэлээ өгөх ажлыг хүн яаж ухамсартайгаар хийдэг вэ? Өдөр тутмынхаа амьдралд та нар Бурханы ажлыг туулж, Түүнд залбирахдаа хааш яаш байдаг—ажиллангаа та нар Бурханд залбирдаг. Үүнийг Бурханд сэтгэл зүрхээ өгч байна гэж хэлж болох уу? Та нар гэр орны асуудал, махан биеийн хэрэг явдлыг бодож байгаа; та нар үргэлж хоёрдмол сэтгэлтэй байдаг. Үүнийг Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж байна гэж үзэж болох уу? Учир нь та нарын зүрх сэтгэл байнга гадаад асуудлууд дээр төвлөрч, Бурханы өмнө буцан ирж чаддаггүй. Хэрэв зүрх сэтгэлээ Бурханы өмнө үнэхээр тайван байлгая гэвэл ухамсартайгаар хамтран ажиллах ёстой. Өөрөөр хэлбэл, та нар дор бүрнээ сүнслэг үйл ажиллагаандаа зориулах цаг болон хүмүүс, үйл явдал, зүйлсийг хойш тавих цагтай байж, зүрх сэтгэлээ Бурханы өмнө тайван байлгах ёстой. Хүн бүр хувийн сүнслэг үйл ажиллагааны тэмдэглэл хөтөлж, гүн гүнзгий ч бай, өнгөцхөн ч бай, Бурханы үгийн талаарх мэдлэг болон сүнс нь хэрхэн хөдөлгөгдсөнийг тэмдэглэх ёстой; бүгд Бурханы өмнө зүрх сэтгэлээ ухамсартайгаар тайван байлгах ёстой. Хэрэв чи өдөр бүр нэг юм уу хоёр цагийг жинхэнэ сүнслэг амьдралд зориулж чадвал тэр өдөр амьдрал чинь баялаг санагдаж, зүрх сэтгэл чинь гэрэлтэй, тодорхой байх болно. Хэрэв чи өдөр бүр иймэрхүү сүнслэг амьдралаар амьдарвал зүрх сэтгэл чинь Бурханы эзэмшилд улам бүр эргэн очиж чадах ба сүнс чинь улам хүчтэй болж, нөхцөл байдал чинь тасралтгүй сайжирч, Ариун Сүнсний удирдан хөтөлдөг замаар алхах чадвар чинь нэмэгдэж, Бурхан чамд улам их ерөөл хайрлана. Сүнслэг амьдралын чинь зорилго бол ухамсартайгаар Ариун Сүнсний дэргэд байх явдал юм. Энэ нь дүрэм журмыг баримталж, эсвэл шашны зан үйл үйлдэх явдал биш, харин Бурхантай үнэхээр хамтран ажиллаж, өөрийн биеийг үнэхээр сахилгажуулах явдал юм—энэ нь хүний хийх ёстой зүйл тул та нар үүнийг туйлын их хичээл чармайлт гарган хийх хэрэгтэй. Хэдий чинээ сайн хамтран ажиллаж, хэдий чинээ их чармайлт гаргана, зүрх сэтгэл чинь төдий чинээ Бурхан руу буцаж чадах бөгөөд чи Түүний өмнө зүрх сэтгэлээ төдий чинээ тайван байлгаж чадна. Тодорхой нэг үед Бурхан зүрх сэтгэлийг чинь бүрэн олж авна. Хэн ч зүрх сэтгэлийг чинь ганхуулж, эсвэл булаан авч чадахгүй ба чи бүрмөсөн Бурханд харьяалагдана. Хэрэв чи энэ замаар алхвал Бурханы үг цаг ямагт чамд аяндаа илчлэгдэж, ойлгодоггүй бүхний чинь талаар чамайг гэгээрүүлнэ—хамтын ажиллагаагаараа дамжуулан энэ бүгдэд хүрч болно. Ийм учраас Бурхан: “Надтай хамтран ажилладаг бүх хүнийг Би хоёр дахин их шагнана” гэж үргэлж хэлдэг. Чи энэ замыг тодорхой харах ёстой. Чи зөв замаар алхахыг хүсдэг бол Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд чадах бүхнээ хийх ёстой. Сүнслэг амьдралд хүрэхийн тулд та нар боломжтой бүхнийг хийх ёстой. Эхэндээ чи энэ эрэл хайгуулд асар их үр дүнд хүрэхгүй байж болох ч

ухарч буцах юм уу сөрөг байдалд хутгалдахыг өөртөө зөвшөөрөх ёсгүй—харин шаргуу ажилласаар л байх ёстой! Сүнслэг амьдралаар амьдрах тусам зүрх сэтгэл чинь Бурханы үгэнд улам эзэмдүүлж, эдгээр асуудалд үргэлж санаа зовж, энэ ачааг үргэлж үүрнэ. Дараа нь сүнслэг амьдралаараа дамжуулан сэтгэлийн гүн дэх үнэнээ Бурханд илчил; юу хийхийг хүсэж байгаагаа, юун тухай бодож байгаагаа, Түүний үгийг юу гэж ойлгож, юу гэж үзэж байгаагаа Түүнд хэл. Юуг ч, бүр өчүүхэн жаахныг ч бүү нуу! Зүрх сэтгэлдээ байгаа үгийг хэлж, Бурханд үнэн сэтгэлээ илчилж дад; зүрх сэтгэл дотор чинь байгаа л бол боломжтой бүх аргаар үүнийгээ хэл. Ийм маягаар ярих тусмаа чи Бурханы хайр татам байдлыг улам мэдэрч, зүрх сэтгэл чинь Бурханд улам хүчтэй татагдана. Ийм зүйл тохиолдох үед чи Бурхан чамд өөр хэнээс ч илүү ойр дотно гэдгийг мэдэрнэ. Чи юу ч болж байсан Бурханы хажуугаас огт холдохгүй. Хэрэв чи өдөр бүр ийм сүнслэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, үүнийг зориуд марталгүй, харин амьдралд чинь асар их ач холбогдолтой зүйл гэж үздэг бол Бурханы үг зүрх сэтгэлийг чинь эзэмдэнэ. Ариун Сүнс сэтгэл хөдөлгөх гэж үүнийг хэлдэг. Тэгээд зүрх сэтгэлийг чинь Бурхан үргэлж эзэмдэж байсан мэт, хайрладаг зүйл чинь үргэлж зүрх сэтгэлд чинь байсан мэт байх болно. Хэн ч чамаас үүнийг булаан авч чадахгүй. Ийм зүйл тохиолдоход Бурхан үнэхээр дотор чинь амьдарч, зүрх сэтгэлд чинь байр эзэлнэ.

ТӨГС БОЛГУУЛСАН ХҮМҮҮСТ ӨГӨХ АМЛАЛТ

Хүнийг төгс болгодог Бурханы зам гэж юу вэ? Үүнд ямар талууд багтдаг вэ? Чи Бурханаар төгс болгуулахад бэлэн үү? Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн үү? Чи эдгээр асуултын талаар юу мэдэх вэ? Хэрвээ чи ийм мэдлэгийн талаар ярьж чадахгүй бол Бурханы ажлыг мэддэггүй хэвээр, Ариун Сүнс чамайг огтхон ч гэгээрүүлээгүйг энэ нь нотолж байна. Ийм хүмүүсийг төгс болгох боломжгүй. Тэдэнд түрхэн зуур эдлэх багахан хэмжээний нигүүлслийг л өгдөг бөгөөд энэ нь удаан үргэлжлэхгүй. Бурханы нигүүлслийг л эдэлдэг бол хүмүүс Бурханаар төгс болгуулж чадахгүй. Зарим хүн махан биеийн амар амгалан, зугаа цэнгэлийг эдэлж, амьдрал нь саад тотгор, золгүй явдалгүй, амар хялбар, гэр бүлээрээ ямар ч хэрүүл, тэмцэлгүй эвтэй найртай амьдрахдаа сэтгэл хангалуун байдаг. Тэд бүр үүнийгээ Бурханы ерөөл хэмээн итгэдэг байж болох ч яг үнэндээ бол энэ нь ердөө л Бурханы нигүүлсэл билээ. Та нар Бурханы нигүүлслийг эдлэх төдийдөө сэтгэл ханаж болохгүй. Ийм сэтгэлгээ бол үнэхээр бүдүүлэг юм. Чи өдөр бүр Бурханы үгийг уншиж, өдөр бүр залбирч, сүнс чинь үлэмж их таашаал, онцгой их амар амгаланг мэдэрдэг ч гэсэн, эцэстээ чи Бурхан болон Түүний ажлын тухай мэдлэгийнхээ талаар хэлэх үггүй, юу ч мэдрээгүй, Бурханы үгийг хэчнээн их идэж, уухаас үл хамааран сүнсээрээ л амар амгалан болон таашаалыг мэдэрч, Бурханы үг юутай ч харьцуулшгүй сайхан, эдлээд ханамгүй мэт санагддаг боловч Бурханы

үгийн ямар ч бодит туршлага, ямар ч бодит байдал чамд байдаггүй бол Бурханд итгэх ийм итгэлээс чи юу олж авч чадах юм бэ? Хэрвээ чи Бурханы үгийн мөн чанарыг амьдран харуулж чаддаггүй бол эдгээр үгийг идэж, ууж байгаа байдал болон залбирал чинь шашны итгэл үнэмшлээс өөр юу ч биш. Ийм хүмүүсийг Бурхан төгс болгож, авч чадахгүй. Бурханаар авхуулсан хүмүүс бол үнэнийг эрэлхийлдэг хүмүүс юм. Бурханы олж авдаг зүйл нь хүний махан бие биш, түүнд харьяалагддаг зүйлс биш, харин түүний дотор байдаг Бурханд харьяалагддаг хэсэг юм. Тиймээс Бурхан хүмүүсийг төгс болгохдоо махан биеийг нь биш, харин зүрх сэтгэлийг нь төгс болгосноор тэдний зүрх сэтгэлийг Бурхан авах боломжтой болдог. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг төгс болгодог гэдэг нь мөн чанартаа бол Бурхан хүний зүрх сэтгэлийг төгс болгодог бөгөөд ингэснээр энэхүү зүрх сэтгэл нь Бурхан руу эргэж, Түүнийг хайрлаж болох юм.

Хүний бие мах, цуснаас бүтдэг. Бурханы хувьд хүний махан биеийг олж авах ямар ч хэрэггүй, учир нь энэ бол гарцаагүй илжирч мууддаг зүйл бөгөөд Бурханы өв, ерөөлийг хүлээн авч чадахгүй. Хэрвээ хүний махан биеийг авдаг, хүний махан бие л энэ урсгалд байдаг байсан бол хүн энэ урсгалд нэр төдий л байх боловч зүрх сэтгэл нь Сатанд харьяалагдах байсан. Тийм учраас хүмүүс Бурханы илрэл болж чадахгүйгээр үл барам, харин ч бас л Түүнд дараа болж, Бурхан хүмүүсийг сонгох нь ямар ч утга учиргүй болох байсан. Бурханы төгс болгохоор зорьж буй хүмүүс бүгд Түүний ерөөл болон өвийг хүлээн авна. Өөрөөр хэлбэл, тэд Бурханд юу байгаа, Тэр юу болохыг шингээн авч, ингэснээр энэ нь тэдэнд байдаг зүйл болдог; Бурханы бүх үгийг тэдэнд оруулж өгсөн байдаг; Бурхан юу ч байлаа гэсэн, та нар энэ бүгдийг яг байгаагаар нь шингээн авч, тэгснээрээ үнэнийг амьдран харуулж чаддаг. Энэ бол Бурханаар төгс болгуулж, Бурханаар авхуулдаг хүн юм. Ийм хүн л Бурханы хайрласан ерөөлийг хүртэх эрхтэй:

1. Бурханы хайрыг бүхэлд нь олж авах.
2. Бүх зүйл дээр Бурханы хүслийн дагуу үйлдэх.
3. Бурханы удирдамжийг олж авч, Бурханы гэрэлд амьдарч, Бурханы гэгээрлийг олж авах.
4. Бурханы хайрладаг дүрийг газар дээр амьдран харуулж; Бурханы төлөө цовдлогдон, үхлээрээ Бурханы хайрыг хариулах эрхтэй болсон Петрийн адил Бурханыг үнэхээр хайрлаж; Петртэй адил алдар суутай байх.
5. Газар дээрх бүх хүнээр хайрлуулж, хүндлүүлж, бишрүүлэх.
6. Үхэл болон үхэгсдийн орны хүлээсийг бүхий л талаар даван гарч, Сатаны ажилд ямар ч боломж өгөлгүй, Бурханаар эзэмдүүлж, шинэ соргог, гал цогтой сүнсэнд амьдарч, залхаж ядардаггүй байх.
7. Бурханы алдрын өдөр ирж буйг харсан мэт бүхий л амьдралынхаа туршид үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөр, догдлолыг ямагт мэдэрдэг байх.
8. Бурхантай хамт алдрыг хүртэж, Бурханы хайртай ариун хүмүүстэй адил төрхтэй байх.

9. Газар дээрх Бурханы хайрладаг нэгэн, өөрөөр хэлбэл, Бурханы хайртай хүү болох.
10. Хэлбэрээ өөрчлөн, Бурхантай хамт гурав дахь тэнгэр өөд гарч, махан биеийг даван гарах.

Бурханы ерөөлийг өвлөж чаддаг хүмүүс л Бурханаар төгс болгуулж, авхуулдаг. Эдүгээ чи ямар нэгэн зүйл олж авсан уу? Бурхан чамайг ямар хэмжээнд төгс болгосон бэ? Бурхан хүнийг санаандгүйгээр төгс болгодоггүй; хүнийг Тэрээр болзолтойгоор төгс болгодог бөгөөд илэрхий, харагдахуйц үр дүнтэй байдаг. Энэ нь, Бурханд итгэж байгаа цагт Бурханаар төгс болгуулж, авхуулж чадахын дээр, газар дээр Бурханы ерөөл, өвийг хүлээн авч чадна хэмээн хүний төсөөлдөг шиг биш юм. Тийм зүйлс нь дэндүү хэцүү бөгөөд хэлбэрээ өөрчлөх тухайд бол ярихын ч хэрэггүй. Эдүгээ та нарын голчлон эрж хайх ёстой зүйл бол бүх зүйл дээр Бурханаар төгс болгуулж, өөрт тулгарсан бүх хүн, хэрэг явдал, зүйлээр дамжуулан Бурханаар төгс болгуулах явдал юм, ингэснээр Бурхан юу болохыг илүү ихээр та нарт оруулах болно. Та нар эхлээд Бурханы өвийг газар дээр хүлээн авах ёстой; тэгсэн цагт л Бурханаас илүү их, илүү агуу ерөөлийг өвлөх эрхтэй болно. Энэ бүгд нь та нарын эрж хайх ёстой, юуны өмнө ойлгох ёстой зүйл юм. Бүх зүйл дээр Бурханаар төгс болгуулахаар эрж хайх тусмаа чи бүх зүйлээс Бурханы гарыг төдий чинээ их харж чадах бөгөөд тэгснээр янз бүрийн хэрэг явдал дээр, янз бүрийн өнцгөөс Бурханы үгийн оршихуй болон Түүний үгийн бодит байдал руу орохоор идэвхтэйгээр эрж хайна. Чи нүгэл үйлдэхгүй, ямар ч үзэлгүй, амьдралын гүн ухаангүй, хүний хүсэл зориггүй байх төдийхнөөр сөрөг байдалдаа сэтгэл хангалуун болж болохгүй. Бурхан хүнийг үй олон аргаар төгс болгодог; бүх хэрэг явдалд төгс болгуулах боломж бий бөгөөд олж авсан зүйлийг чинь илүү баяжуулахын тулд Тэр чамайг эерэг талаас нь төдийгүй сөрөг талаас нь ч бас төгс болгож чадна. Бурханаар төгс болгуулах боломж, авхуулах тохиол өдөр болгон гарч байдаг. Хэсэг хугацаанд ийнхүү туршлагажсаны дараа чи асар их өөрчлөгдөж, өмнө нь мэддэггүй байсан маш олон зүйлийг аяндаа ойлгоно. Бусдаар заалгах хэрэггүй; мэдээгүй байхад чинь Бурхан чамайг гэгээрүүлэх болно, ингэснээр чи бүх зүйл дээр гэгээрлийг олж, бүх туршлагадаа илүү нарийн орно. Бурхан чамайг баруун зүүн тийш хэлбийлгэхгүйгээр залж чиглүүлнэ. Тэгээд чи Түүгээр төгс болгуулах замд хөл тавина.

Бурханаар төгс болгуулахыг, Бурханы үгийг идэж ууснаар төгс болох явдлаар хязгаарлаж болохгүй. Иймэрхүү туршлага нь хэтэрхий өрөөсгөл, хэтэрхий багыг багтаадаг бөгөөд хүмүүсийг маш бага хүрээнд хязгаарлахаас өөр аргагүй болно. Тийм учраас хүмүүс шаардлагатай сүнслэг шим тэжээлээр ихээхэн дутагдах болно. Хэрвээ та нар Бурханаар төгс болгуулахыг хүсэж байвал бүх зүйл дээр хэрхэн туршлагажихыг сурч, өөрт тохиолдож буй бүхнээс гэгээрлийг олж авч чаддаг байх ёстой. Сайн ч бай, муу ч бай чи үүнээс үр ашиг хүртэх ёстой бөгөөд энэ нь чамайг сөрөг болгох ёсгүй. Юу ч болсон бай, чи хүний харах өнцгөөс юмыг задлан шинжилж, судлах (ингэх нь чиний туршлагын гажуудал болно) биш Бурханы

талд зогсож байхдаа юмыг дэнсэлж чаддаг байх ёстой. Хэрвээ чи ингэж туршлагаждаг бол зүрх сэтгэл чинь чиний амийн ачаагаар дүүрэх болно; чи байнга Бурханы дүр төрхийн гэрэлд амьдарч, хэрэгжүүлэлтийнхээ хувьд тийм ч амар хазайхгүй. Ийм хүмүүсийн өмнө гэгээлэг ирээдүй байдаг. Бурханаар төгс болгуулах маш олон боломж бий. Энэ бүгд нь та нар Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс мөн эсэхээс, Бурханаар төгс болгуулж, Бурханаар авхуулж, Түүний ерөөл, өвийг хүлээн авах шийдэмгий байдал та нарт байгаа эсэхээс хамаардаг. Зөвхөн шийдэмгий байдал байгаад хангалтгүй. Та нар ихээхэн мэдлэгтэй байх ёстой, эс бөгөөс хэрэгжүүлэлтээсээ үргэлж хазайх болно. Бурхан та нарыг нэг бүрчлэн төгс болгохыг хүсдэг. Одоогийн байдлаар, ихэнх хүн Бурханы ажлыг аль хэдийн удаан хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэдий ч Бурханы нигүүлслийг эдлэх төдийхнөөр өөрсдийгөө хязгаарлагдаж, Түүнээс махан биеийн багахан тав тухыг хүлээн авахыг л хүсэж байдаг атлаа илүү их, илүү өндөр илчлэл хүлээн авахыг хүсдэггүй бөгөөд хүний зүрх сэтгэл үргэлж гадна байсаар байгаа гэдгийг энэ нь харуулдаг. Хэдийгээр хүний ажил, үйлчлэл болон Бурханыг гэх хайрын сэтгэлд нь сэв арай бага байдаг ч дотоод гол чанар, хоцрогдмол сэтгэлгээнийх нь тухайд бол хүн махан биеийн амар амгалан, зугаа цэнгэлийг байнга эрж хайсаар байдгийн дээр хүнийг төгс болгох Бурханы нөхцөл болон зорилго юу болохыг ойшоодоггүй. Иймээс ихэнх хүний амьдрал бүдүүлэг, доройтсон хэвээр, өчүүхэн төдий ч өөрчлөгдөөгүй. Тэд зүгээр л Бурханд итгэх итгэлийг чухал зүйл гэж үздэггүй, бусдын төлөө л итгэж байгаа юм шиг, хэлбэр төдий хийж, хааш яаш аргацаан, урсгал даган зорилгогүй амьдардаг. Цөөн хэд нь л бүх зүйл дээр Бурханы үг рүү орохоор эрж хайж чаддаг, илүү их, баялаг зүйлсийг олж авч, өнөөдөр Бурханы гэр дэх үлэмж их хөрөнгөтэй хүмүүс болж, Бурханы ерөөлийг илүү их хүлээн авдаг хүмүүс юм. Хэрвээ чи бүх зүйл дээр Бурханаар төгс болгуулахаар эрж хайж, газар дээр Бурханы амласан зүйлийг хүлээн авч чаддаг бол, хэрвээ чи бүх зүйл дээр Бурханаар гэгээрүүлэгдэхээр эрж хайж, цаг хугацааг дэмий өнгөрөөдөггүй бол идэвхтэйгээр ороход хамгийн тохирсон зам энэ мөн билээ. Ийм маягаар л чи Бурханаар төгс болгуулах үнэ цэнтэй, эрхтэй байна. Чи Бурханаар төгс болгуулахаар эрж хайдаг нэгэн үнэхээр мөн үү? Чи бүх зүйл дээр үнэн сэтгэлээсээ ханддаг нэгэн үнэхээр мөн үү? Петртэй адил Бурханыг гэсэн хайрын сэтгэл чамд байдаг уу? Есүс шиг Бурханыг хайрлах хүсэл зориг бий юу? Чи олон жилийн турш Есүст итгэж ирсэн; Есүс Бурханыг хэрхэн хайрлаж байсныг чи харсан уу? Чиний итгэдэг нэгэн үнэхээр Есүс мөн үү? Чи өнөөдрийн бодитой Бурханд итгэдэг; махбод дахь бодитой Бурхан тэнгэр дэх Бурханыг хэрхэн хайрладгийг чи харсан уу? Эзэн Есүс Христэд чи итгэдэг; яагаад гэвэл хүн төрөлхтнийг золин аврахын төлөө Есүс цовдлогдсон, Түүний үйлдсэн гайхамшиг нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэн юм. Гэхдээ хүний итгэл нь Есүс Христийн тухай мэдлэг болон жинхэнэ ойлголтоос гардаггүй. Чи Есүсийн нэрд нь л итгэдэг боловч Түүний Сүнсэнд итгэдэггүй, учир нь чи Есүс Бурханыг хэрхэн хайрлаж байсныг огт ойшоодоггүй билээ. Бурханд итгэх итгэл чинь хэтэрхий гэнэн.

Чи Есүст олон жил итгэсэн хэр нь Бурханыг хэрхэн хайрлахаа мэддэггүй. Энэ нь чамайг энэ дэлхийн хамгийн тэнэг хүн болгож байгаа бус уу? Эзэн Есүс Христийн хоолыг олон жил хий дэмий идсэний чинь нотолгоо энэ байна. Би ийм хүмүүст дургүйгээр барахгүй, чиний дээдэлдэг Эзэн Есүс Христ ч гэсэн бас дургүй гэдэгт Би итгэдэг. Ийм хүмүүс яаж төгс болгуулж чадах юм бэ? Ичсэндээ нүүр чинь улайхгүй байна гэж үү? Ичихгүй байна уу? Эзэн Есүс Христээ харах нүүр чамд байсаар байна уу? Та нар бүгдээрээ Миний хэлсэн үгийн утга учрыг ойлгож байна уу?

ХОРОН МУУ ХҮМҮҮС ГАРЦААГҮЙ ШИЙТГҮҮЛНЭ

Хийдэг бүхэндээ зөв шударга байдлыг хэрэгжүүлдэг эсэхээ, мөн бүх үйлдлийг чинь Бурхан ажиглаж байгаа эсэхийг мэдэхийн тулд өөрсдөдөө дүн шинжилгээ хий: Бурханд итгэдэг хүмүүсийн үйл хэргийн зарчим энэ юм. Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаг, мөн Бурханы халамж, хамгаалалтыг хүлээн авдаг учраас та нар зөв шударга гэж нэрлэгдэнэ. Бурханы халамж, хамгаалалт, төгс болголтыг хүлээн авдаг, Түүгээр авхуулсан бүх хүн Бурханы нүдэнд зөв шударга бөгөөд тэднийг бүгдийг нь Бурхан эрхэм нандин гэж үздэг. Чи Бурханы одоогийн үгийг хүлээн авах тусмаа Бурханы хүслийг төдий чинээ хүлээн авч, ойлгож чадна, тэгснээр Бурханы үгийг төдий чинээ амьдран харуулж, Түүний шаардлагыг хангаж чадна. Энэ нь та нарт өгсөн Бурханы даалгавар бөгөөд та бүхний биелүүлж чадах зүйл юм. Хэрвээ та нар өөрсдийн үзлээр Бурханыг өөрчлөгдөшгүй шавар хөшөө аятай хэмжиж, хязгаарладаг бол, Бурханыг тэр чигт нь Библийн хэмжүүрээр хязгаарлаж, хязгаарлагдмал цар хүрээний ажлаар хайрцагладаг бол Бурханыг ялласан гэдгийг чинь энэ нь баталдаг. Хуучин Гэрээний эрин үед иудейчүүд Бурханыг Мессиа л гэж нэрлэж болох мэт, Мессиа гэгддэг Нэгэн л Бурхан байж болох юм шиг Бурханыг өөрсдийнхөө зүрх сэтгэлдээ тээдэг тогтсон хэлбэртэй шүтээн шигээ бодсон учраас, мөн хүн төрөлхтөн Бурханд (амьгүй) шавар хөшөө мэт үйлчилж, шүтэн мөргөдөг байсан учраас тухайн үеийн Есүсийг загалмайд цовдолж, үхлийн ял оноосон бөгөөд гэмгүй Есүсийг тийнхүү үхлээр ялласан юм. Бурхан ямар ч гэм буруугүй байсан атал хүн Түүнийг өршөөхөөс татгалзаж, үхлийн ял оноохоор зүтгэсэн болохоор Есүс цовдлогдсон билээ. Хүн Бурханы удирдлагад төгс нэвтэрсэн мэт, Бурханы хийдэг бүхнийг гарын арван хуруу шигээ мэддэг юм шиг Бурханыг өөрчлөгдөшгүй гэж үргэлж боддог бөгөөд ганцхан ном буюу Библийн үндсэн дээр Түүнийг тодорхойлдог. Хүмүүс дэндүү утгагүй, дээд зэргээр биеэ тоосон байдаг ба бүгдээрээ дэгсдүүлэх чадвартай. Бурханы тухай мэдлэг чинь хэр их байх нь хамаагүй, Би чамайг бас л Бурханыг мэддэггүй, Бурханыг хамгийн их эсэргүүцдэг хүн, мөн Бурханыг ялласан гэж хэлдэг, учир нь чи Бурханы ажлыг дуулгавартай дагах, Бурханаар төгс болгуулах замаар алхах ямар ч чадваргүй. Яагаад Бурхан хүний үйлдэлд хэзээ ч сэтгэл ханадаггүй вэ? Учир нь хүн хэтэрхий их үзэлтэй

болохоороо Бурханыг мэддэггүй бөгөөд Бурханы тухай мэдлэг нь бодит байдалтай өчүүхэн ч нийцдэггүй, харин нэг сэдвийг өөрчлөлтгүйгээр, нэгэн хэмээр давтаж, нөхцөл байдал болгонд нэг аргаа ашигладаг. Иймээс өнөөдөр Бурхан газар дээр ирээд хүнээр дахин нэг удаа загалмайд цовдлуулсан. Харгис хүн төрөлхтөн! Нэг нэгнийхээ эсрэг хуйвалдах, булаалцаж тэмцэлдэх, алдар нэр, ашиг хонжоо булаалдах, харилцан нэг нэгнээ хөнөөх—энэ ер нь хэзээ төгсөх юм бэ? Бурхан олон зуун мянган үг хэлсэн боловч хэн ч сэхээрээгүй. Хүмүүс гэр бүл, хөвгүүд, охид, ажил мэргэжил, хэтийн ирээдүй, байр суурь, хоосон нэр алдар, мөнгөний төлөө, бас хоол хүнс, хувцас хунар, махан биеийн төлөө үйлддэг, харин үйлдэл нь үнэхээр Бурханы төлөө байдаг хүн байна уу? Бурханы төлөө үйлддэг хүмүүсийн дунд ч гэсэн Бурханыг мэддэг хүн цөөхөн. Өөрсдийнхөө ашиг сонирхлын төлөө үйлддэггүй хүн хэд вэ? Өөрсдийн байр суурийг хамгаалахын тулд бусдыг дарлаж, гадуурхдаггүй хүн хэчнээн бэ? Иймээс Бурханд тоймгүй олон удаа үхэх ял хүчээр тулгасан, мөн тоо томшгүй олон хэрцгий шүүгч Бурханыг яллаж, дахин нэг удаа загалмайд цовдолсон. Үнэхээр Бурханы төлөө үйлддэг учраас зөв шударга гэж нэрлэгдэж болох хүн хэд байдаг вэ?

Бурханы өмнө ариун хүн юм уу зөв шударга хүн болж төгс болгуулах маш амархан уу? “Энэ газар дэлхий дээр зөв шударга хүн үгүй, зөв шударга нь энэ дэлхийд үгүй” гэдэг нь үнэн үг юм. Бурханы өмнө очих үедээ та нар юу өмсөж байгаагаа, үг, үйлдэл бүрээ, бодол, санаа болгоноо, тэр ч бүү хэл өдөр бүр зүүдэлдэг зүүдээ цэгнээд үз—эдгээр нь бүгд өөрсдийн чинь төлөө байдаг. Хэрэг явдлын үнэн байдал энэ биш гэж үү? “Зөв шударга байдал” гэдэг нь бусдад өглөг өгнө гэсэн үг биш, хөршөө өөр шигээ хайрлана гэсэн үг биш, мөн маргаж, хэрэлдэх, дээрэмдэж, хулгай хийхийг цээрлэнэ гэсэн үг биш юм. Зөв шударга байдал гэдэг нь Эзэн Есүсийн хийсэн бүхэнтэй адилаар цаг хугацаа, орон зайг үл харгалзан Бурханы даалгаврыг өөрийн үүрэг гэж авч үзэн, Бурханы зохион байгуулалт, зохицуулалтыг тэнгэрээс илгээсэн ажил мэргэжил хэмээн дуулгавартай дагана гэсэн үг юм. Энэ бол Бурханы ярьсан зөв шударга байдал мөн. Лот өөрийнхөө ашиг, алдагдлыг бодож үзэлгүйгээр Бурханы илгээсэн хоёр тэнгэрэлчийг аварсан болохоор зөв шударга хүн хэмээн нэрлэгдэж чадсан; тухайн үед түүний хийсэн зүйлийг зөв шударга гэж нэрлэж болох боловч түүнийг зөв шударга хүн гэж нэрлэж болохгүй гэж л хэлж болно. Лот Бурханыг харсан учраас л хоёр охиноо тэнгэрэлчүүдийн оронд өгсөн болохоос биш түүний урьдын бүх зан авир нь зөв шударга байдлын төлөө байгаагүй юм. Иймээс Би “энэ газар дэлхий дээр зөв шударга хүн үгүй” гэж хэлдэг. Сэргэлтийн урсгалд байгаа хүмүүсээс хүртэл хэнийг нь ч зөв шударга гэж нэрлэх боломжгүй. Чиний үйлдэл хэчнээн сайн байлаа ч, чи Бурханы нэрийг хэчнээн их алдаршуулдаг мэт харагдлаа ч хамаагүй, бусдыг цохиж хараадаггүй, бусдаас хулгайлж дээрэмддэггүй байлаа ч гэсэн чамайг бас л зөв шударга гэж нэрлэж болохгүй, учир нь энэ бол хэвийн хүний эзэмшиж чадах зүйл билээ. Яг одоо гол нь юу вэ гэвэл, чи Бурханыг мэддэггүй. Одоогоор чамд бага

зэрэг хэвийн хүн чанар байгаа ч Бурханы ярьсан зөв шударга байдлын ямар ч элемент байхгүй гэж хэлж болно, иймээс чиний хийж байгаа зүйлсийн аль нь ч Бурханыг мэддэг гэдгийг чинь нотолж чадахгүй.

Өмнө нь, Бурханыг тэнгэрт байх үед хүн Түүнийг хуурах үйлдэл гаргадаг байлаа. Өнөөдөр Бурхан хүмүүсийн дунд байгаа, хэчнээн олон жил болсныг хэн ч мэдэхгүй, гэхдээ хүн аливааг хийхдээ бас л дүр эсгэж, Түүнийг хуурахыг оролдсоор л байна. Хүний бодол хэтэрхий хоцрогдмол биш гэж үү? Иудас ч гэсэн ийм байсан: Есүсийг ирэхээс өмнө тэр үргэлж худал хэлж, ах эгч нараа хуурдаг байсан, Есүсийг ирсний дараа ч гэсэн өөрчлөгдөөгүй; тэр Есүсийг өчүүхэн төдий ч мэддэггүй байсан бөгөөд эцэст нь Есүсээс урвасан юм. Энэ нь Бурханыг мэддэггүй байснаас нь болсон бус уу? Хэрвээ өнөөдөр та нар Бурханыг мэдэхгүй хэвээр байгаа бол та нар өөр нэгэн Иудас болж, үүнээс үүдэн хоёр мянган жилийн өмнөх Нигүүлслийн эрин үед Есүсийг цовдолсон эмгэнэлт явдал дахин давтагдах боломжтой. Та нар үүнд итгэхгүй байна уу? Энэ бол баримт! Одоогоор ихэнх хүн иймэрхүү нөхцөл байдалтай байгаа (Би үүнийг арай эрт хэлж байж магадгүй) ба ийм хүмүүс бүгд Иудасын дүрд тоглож байгаа юм. Би утгагүй юм яриагүй, харин баримтад үндэслэн ярьж байгаа бөгөөд чи үнэмшихээс өөр аргагүй. Олон хүн даруу төлөв дүр үзүүлдэг ч зүрх сэтгэлд нь тогтоол усан цөөрөм, өмхий усны шуудуунаас өөр юу ч байдаггүй. Яг одоо чуулганд ийм хүн дэндүү олон байгаа бөгөөд та нар Намайг үүнийг огт мэддэггүй гэж боддог. Миний Сүнс өнөөдөр Миний төлөө шийдвэр гаргаж, Надад гэрчлэл хийдэг. Намайг юу ч мэдэхгүй гэж чи бодож байна уу? Та нарын зүрх сэтгэл доторх зальхай бодол, зүрх сэтгэл дотроо хадгалдаг зүйлсийг Намайг огт ойлгодоггүй гэж бодож байна уу? Бурханыг дарлахад ийм амархан гэж үү? Түүнд хүссэнээрээ хандаж болно гэж бодоо юу? Урьд нь Би та нарыг хязгаарлагдах вий гэж санаа зовсондоо эрх чөлөө өгсөөр байсан боловч хүмүүс өөрсдөд нь сайн хандаж байгааг ухаарч чадалгүй, өгөх тусам минь улам даварч байлаа. Нэг нэгнээсээ асууцгаа: Би бараг хэзээ ч, хэнд ч харьцалт хийгээгүй, бараг хэзээ ч, хэнийг ч хялбархан зэмлээгүй, гэсэн ч Би хүний үзэл, сэдлийг маш тодорхой мэднэ. Бурханы гэрчилдэг Бурхан Өөрөө тэнэг гэж чи бодож байна уу? Тийм бол, Би чамайг хэтэрхий харалган байна гэж хэлнэ! Би чамайг илчлэхгүй, харин хэр их завхрахыг чинь л харцгаая. Ухаалаг бяцхан ов мэх чинь чамайг аврах нь уу, Бурханыг хайрлах гэж чадах чинээгээрээ хичээх нь чамайг аврах нь уу гэдгийг харцгаая. Өнөөдөр Би чамайг яллахгүй; Бурханы цаг ирэхэд чамайг хэрхэн залхаан цээрлүүлэхийг харцгаая. Одоо чамтай дэмий чалчих зав алга, ганц чиний төлөө Би илүү агуу ажлаа хойшлуулмааргүй байна. Чам шиг өт хорхойтой харьцах гэж Бурхан цаг заваа зориулахад хайран байна—иймээс хэр садар самуун болохыг чинь л харцгаая. Ийм хүмүүс Бурханы тухай мэдлэгийг өчүүхэн ч эрэлхийлдэггүй, Түүнд өчүүхэн төдий ч хайргүй байдаг атлаа Бурханаар зөв шударга гэж дуудуулахыг хүссээр байдаг—энэ чинь инээдтэй хэрэг биш үү? Цөөн тооны хүн үнэхээр үнэнч байдаг учраас Би хүмүүсийг амиар үргэлжлүүлэн хангахад л

анхаарал хандуулна. Би өнөөдөр хийх ёстой зүйлээ л хийж дуусгана, харин хожим нь хүн бүрд хийсэн зүйлийнх нь дагуу залхаан цээрлүүлэлт авчирна. Би хэлж болох бүхнийг хэллээ, учир нь энэ бол чухам Миний хийдэг ажил юм. Би хийх ёстой зүйлээ л хийдэг, хийх ёсгүй зүйлээ хийдэггүй. Ямартай ч та нар илүү их цаг зарцуулж эргэцүүлэн бодно гэж Би найдаж байна: Бурханы талаарх мэдлэгийн чинь яг хэр зэрэг нь үнэн бэ? Чи Бурханыг дахин нэг удаа загалмайд цовдолсон хүн мөн үү? Эцэст нь хэлэх үг минь энэ: Бурханыг цовдолдог хүмүүс золгүй еэ.

ХЭВИЙН БАЙДАЛД ХЭРХЭН ОРОХ ВЭ

Хүмүүс Бурханы үгийг хүлээн зөвшөөрөх тусмаа улам гэгээрч, Бурханыг мэдэх эрэл хайгуулдаа улам өлсөж, цангадаг. Бурханы үгийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс л илүү гүнзгий, илүү баялаг туршлагатай болох чадвартай бөгөөд амь нь гүнждийн цэцэг дэлгэрэх мэт өсөн дээшилж чадна. Амийг эрэлхийлдэг хүн бүр үүнд бүтэн цагийн ажил мэт хандах ёстой бөгөөд “Бурхангүйгээр амьдарч чадахгүй, Бурхангүйгээр юуг ч бүтээж дийлэхгүй, Бурхангүйгээр бүх зүйл хий хоосон” гэдгийг мэдрэх ёстой юм. Мөн “Ариун Сүнсний дэргэд биш бол би юу ч хийхгүй, Бурханы үгийг уншаад үр дүнд хүрэхгүй бол юу ч хийсэн нэмэргүй” гэсэн шийдвэртэй байх ёстой. Өөрийгөө бүү өөгшүүл. Амийн туршлага нь Бурханы гэгээрэл, удирдамжаас гардаг, мөн та нарын субъектив хүчин зүтгэлийн биелэл юм. “Амийн туршлагын тухайд өөрийгөө хэлтрүүлж болохгүй” гэсэн шаардлагыг та нар өөрсдөдөө тавих ёстой.

Заримдаа хэвийн бус нөхцөл байдалд Бурханыг дэргэдээсээ алдаж, хэчнээн залбираад ч Бурханыг мэдэрч чаддаггүй. Ийм үед айх мэдрэмж төрөх нь хэвийн бөгөөд нэн даруй хайж эхлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол Бурхан чамаас хол байж, чи Ариун Сүнстэй хамт байхгүйгээр, бүр Ариун Сүнсний ажилгүйгээр нэг хоёр өдөр, цаашлаад нэг, хоёр сар болох болно. Ийм нөхцөл байдалд чи улам хөшүүн болж, Сатанд дахин нэгэнтээ олзлогдон, бүх төрлийн үйл үйлдэх хэмжээнд очдог. Чи эд мөнгөнд шунахайрч, ахан дүүсээ хууран мэхэлж, кино, видео үзэж, маажаан даалуу тоглож, бүр ямар ч сахилга батгүйгээр тамхи татаж, архи уудаг. Зүрх сэтгэл чинь Бурханаас холдож, өөрийн замаар далдуур алхаж, Бурханы ажлыг дурааpаа шүүн магадалсан. Зарим тохиолдолд, хүмүүс бүр эр эмийн нүгэл эрээ цээргүй, ичиж зовохгүй үйлдэх ноцтой хэмжээнд ч хүрдэг. Ийм хүн бол Ариун Сүнсэнд хаягдсан хүн юм; үнэндээ ийм хүнээс Ариун Сүнсний ажил аль хэдийн арилж одсон байдаг. Завхралд улам гүн живж, ёрын муу гар нь улам сунаж, эцэст нь энэ замын оршин тогтнолыг үгүйсгэн, нүглийнхээ эрхээр Сатанд олзлогдсон хүнийг л тэднээс харж болно. Хэрэв чи Ариун Сүнсний дэргэд байгаа ч Ариун Сүнсний ажилгүй байгаа бол нөхцөл байдал хэдийн аюултай болжээ. Ариун Сүнсний байгааг ч мэдрэхгүй болох үедээ чи хэдийн үхлийн ирмэгт тулсан байх болно. Хэрэв чи гэмшихгүй бол Сатанд бүрэн эзлэгдэж, таягдан хаягдах хүмүүсийн дунд байна. Тиймээс Ариун

Сүнсний дэргэд л байгаа (гэм нүгэл үйлдэхгүй, садар самуун явдалгүй, Бурханыг илэрхий дорд үзсэн үйлдэл хийхгүй) боловч Ариун Сүнсний ажилгүй (залбирсан ч сэтгэл хөдлөхгүй, Бурханы үгийг идэж уугаад ч илэрхий гэгээрч гийхгүй, Бурханы үгийг идэж уухаас залхуурч хойрголон, аминд ахиц дэвшил гарахгүй, урт удаан хугацаа өнгөрөвч асар их гэрэлтүүлэлтгүй) байгаагаа олж мэдвэл чи энэ үед илүү сэрэмжтэй байх ёстой. Өөрийгөө өөгшүүлж, зан авираа дураар нь тавьж огт болохгүй. Ариун Сүнс аль ч цагт арилан одож мэдэх тул ийм нөхцөл байдал маш аюултай. Хэрэв ийм байдалд орвол аль болох хурдан засахаар хичээ. Юун түрүүнд гэмшлийн залбирал үйлдэн, дахин нэг удаа өршөөхийг Бурханаас гуйх ёстой. Тэгээд үнэн зүрхний угаас залбиран, зүрх сэтгэлээ тайван байлгаж, Бурханы үгийг илүү их идэж уу. Энэ суурин дээр залбирал олонтаа үйлдэж, дуулах, залбирах, Бурханы үгийг идэж уух болон үүргээ биелүүлэхдээ илүү их хичээл чармайлт гаргах ёстой. Чи хамгийн сул дорой байх үедээ Сатанд хамгийн амархан эзлэгддэг. Хэрэв ийм байдал тохиолдвол зүрх сэтгэл чинь Бурханы өмнөөс холдож, Сатан руу буцаж, улмаар чи Ариун Сүнсний дэргэд байхаа больдог. Ийм үед Ариун Сүнсний ажлыг буцаан олж авахад улам хэцүү байдаг. Ариун Сүнстэй хамт байх үедээ ажлыг нь эрж хайвал илүү дээр бөгөөд Бурхан чамайг улам гэгээрүүлж, чамайг хаяж орхихгүй байхад хүрнэ. Залбирах, магтан дуу дуулах, чиг үүрэгтээ үйлчлэх, Бурханы үгийг идэж уух чинь бүгд Сатанд ажлаа хийх боломж олгохгүйн төлөө хийгддэг бөгөөд ингэснээр Ариун Сүнс дотор чинь ажиллаж болох юм. Хэрэв Ариун Сүнсний ажлыг ингэж буцаан олж авалгүй, зүгээр л хүлээх юм бол Ариун Сүнс сэтгэлийг чинь онцгойлон хөдөлгөж, тусгайлан гэрэлтүүлж, гэгээрүүлээгүй л бол Ариун Сүнсийг дэргэдээсээ алдсан байх үед Ариун Сүнсний ажлыг буцаан олж авахад амаргүй байх болно. Тэгээд ч чиний байр байдал ганц, хоёр хоногт сэргэхгүй; заримдаа бүр хагас жилдээ ч сэргэхгүй байж мэднэ. Энэ бүхэн хүмүүс өөрсдийгөө дураар нь тавьж, хэвийн байдлаар туршлагажиж чадалгүй, улмаар Ариун Сүнсэнд хаягддагаас үүдэлтэй. Чи Ариун Сүнсний ажлыг буцаан олж авлаа ч гэсэн Бурханы одоогийн ажлыг мөн л тийм ч тодорхой ойлгохгүй байж мэднэ, учир нь амийн чинь туршлага асар хол, арван мянган бээрийн алсад шахам хоцорчээ. Энэ аймшигтай биш гэж үү? Гэсэн ч Би тийм хүмүүст гэмшихэд одоо ч оройтоогүй гэж хэлдэг, гэхдээ ганц л болзол бий: Тэр нь биеэ дайчилж, залхуурахгүй байх явдал юм. Бусад хүн өдөрт таван удаа залбирч байгаа бол чи арван удаа залбирах ёстой; бусад хүн өдөр хоёр цаг Бурханы үгийг идэж ууж байгаа бол чи дөрвөөс зургаан цаг идэж уух ёстой; бусад хүн хоёр цаг магтан дуу сонсдог бол чи хамгийн багадаа хагас өдөр сонсох ёстой. Бурханы өмнө үргэлж тайван байж, Бурханы хайрыг бод, сэтгэл чинь хөдөлж, зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэн очиж, Бурханаас дахин холдож зүрхлэхээ болих тэр цагт л чи урьдын, хэвийн байдалдаа эргэн орно.

Зарим хүн эрэл хайгуулдаа ихээхэн урам зоригтой байдаг ч зөв замд орж чаддаггүй. Учир нь тэд дэндүү хэнэггүй бөгөөд сүнслэг зүйлд огт анхаарал

хандуулдаггүй. Тэд Бурханы үгийг хэрхэн туулахаа мэддэггүй, Ариун Сүнстэй хамт байх болон Ариун Сүнсний ажил юу болохыг огт мэддэггүй. Ийм хүмүүс урам зоригтой байдаг боловч мунхаг юм; тэд амийг эрэлхийлдэггүй. Учир нь чи Сүнсний тухай өчүүхэн төдий ч мэдлэггүй, Ариун Сүнсний одоогийн ажлын хөгжил дэвшлийн талаар юу ч мэддэггүй, өөрийнхөө сүнсэн дэх байдлыг ч мэддэггүй. Ийм хүмүүсийн итгэл будилуу бус уу? Ийм хүмүүсийн эрэл хайгуул эцэстээ юунд ч хүрдэггүй. Бурханд итгэх итгэлдээ амийн өсөлтөд хүрэх гол түлхүүр нь Бурхан ямар ажил хийдгийг туршлагаараа мэдэж, Бурханы хайр татам байдлыг харж, Бурханы хүслийг ойлгох явдал бөгөөд ингэснээр чи Бурханы бүх зохицуулалтад захирагдаж, Бурханы үгийг амиа болгохын тулд өөртөө шингээж, улмаар Бурханыг сэтгэл хангалуун болгодог. Хэрэв итгэл чинь будилуу бол, хэрэв чи сүнслэг хэрэг явдалд ямар ч анхаарал хандуулдаггүй, үнэнд ямар ч хүчин чармайлт гаргадаггүй бол Бурханы хүслийг ухаарч чадах уу? Хэрвээ чи Бурханы шаарддаг зүйлийг ойлгодоггүй бол туршлагажиж чадахгүй, улмаар хэрэгжүүлэлтийн замгүй байх болно. Бурханы үгийг туулахдаа чамд гаргадаг үр нөлөөг нь анхаарах ёстой бөгөөд ингэснээр чи Бурханыг үгээс нь мэдэж авч болох юм. Хэрвээ чи Бурханы үгийг уншихаа л мэддэг боловч яаж туулахаа мэддэггүй бол сүнслэг асуудлыг мэддэггүйг чинь энэ нь харуулдаг бус уу? Яг одоо ихэнх хүн Бурханы үгийг туулж чаддаггүй, тиймээс Бурханы ажлын талаар мэддэггүй. Энэ нь хэрэгжүүлж чадахгүй байгаа хэрэг бус уу? Хэрэв энэ маягаар үргэлжлүүлсээр байвал тэд хэзээ баялаг туршлагатай болж, амийн өсөлтөд хүрч чадах юм бэ? Энэ нь ердөө хоосон яриа болох бус уу? Та нарын дунд онолд анхаарлаа төвлөрүүлдэг, сүнслэг асуудлын талаар юу ч мэддэггүй хэрнээ Бурханаар асар их ашиглуулахыг, Бурханаар ерөөгдөхийг хүссээр байдаг хүн олон бий. Энэ нь огтхон ч бодитой бус! Тиймээс та нар энэ дутагдлаа төгсгөл болгох ёстой. Тэгж гэмээнэ бүгд сүнслэг амьдралын зөв замд орж, жинхэнэ туршлагатай болж, Бурханы үгийн бодит байдалд үнэхээр орж болох юм.

ХЭРХЭН БУРХАНЫ ХҮСЭЛД НИЙЦҮҮЛЭН ҮЙЛЧЛЭХ ВЭ

Хүн Бурханд итгэхдээ Түүнд яг яаж үйлчлэх ёстой вэ? Бурханд үйлчилдэг хүмүүс ямар нөхцөл байдлыг хангаж, ямар үнэнийг ойлгосон байх ёстой вэ? Мөн та нарын үйлчлэл хаана гажууддаг байж болох вэ? Энэ бүхний хариултыг та нар мэддэг байх ёстой. Эдгээр асуудал нь Бурханд хэрхэн итгэх, Ариун Сүнсний хөтөлсөн замаар хэрхэн алхах, мөн бүх зүйл дээр Бурханы зохион байгуулалтад хэрхэн захирагдах талаар хөндсөнөөрөө та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийг ойлгох боломжийг та бүхэнд олгох болно. Та нар тэр түвшинд хүрэх үедээ Бурханд итгэх итгэл гэж юу болох, Бурханд хэрхэн зөв зохистой итгэх, Бурханы хүсэлд нийцүүлэн юу хийх хэрэгтэйг ойлгоно. Энэ нь та нарыг Бурханы ажилд

бүрэн дүүрэн, туйлын дуулгавартай болгоно; та нар Бурханы ажилд гомдоллохгүй, Түүнийг шүүж, задлан шинжлэхгүй, тэр ч бүү хэл судлахгүй. Тийм болохоор, та бүхэн үхэн үхтлээ Бурханд дуулгавартай байх чадвартай болж, Бурханаар удирдуулан жолоодуулж, өөрсдийгөө хонь шиг нядлахыг Бурханд зөвшөөрснөөрөө 1990-ээд оны Петр болж, загалмай дээр байсан ч гэсэн өчүүхэн ч гомдолгүйгээр Бурханыг хамгийн ихээр хайрлаж чадна. Зөвхөн тэгсэн цагт л та нар 1990-ээд оны Петр шиг амьдарч чадна.

Шийдсэн хүн бүхэн Бурханд үйлчилж чадна—гэхдээ зөвхөн Бурханы хүсэлд бүхий л талаар санаа тавьдаг, Бурханы хүслийг ойлгодог хүмүүс л Бурханд үйлчлэх эрхтэй, шаардлага хангасан байх ёстой. Би үүнийг та нарын дундаас олж мэдсэн: Бурханы төлөө гал халуунаар сайн мэдээ түгээж, Бурханы төлөө цааш явж, Бурханы төлөө өөрсдийгөө зарлагадаж, аливаа зүйлээс татгалзах гэх мэтийг хийж байгаа цагт энэ нь Бурханд үйлчилж байгаа хэрэг гэж олон хүн боддог. Бурханд үйлчлэх гэдэг нь гартаа Библи барин, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээж, гэмшүүлж, улайлгах замаар хүмүүсийг аврах явдал гэж шашны бүр ч олон хүн боддог. Мөн Бурханд үйлчлэх гэдэг нь шашны сургуульд сурч, боловсорсны дараа сүмд номлож, Библийн судраас унших замаар хүмүүст зааж сургах явдал юм гэж боддог шашны олон албан тушаалтан бий. Түүнчлэн Бурханд үйлчлэх гэдэг нь ах эгч нарынхаа дундаас өвчтэйг нь эдгээж, чөтгөрүүдийг нь хөөн зайлуулж, эсвэл тэдний төлөө залбирч, тэдэнд үйлчлэх явдал гэж ядуу тарчиг газар нутгийн хүмүүс үздэг. Бурханд үйлчлэх гэдэг нь өдөр бүр Бурханы үгийг идэж ууж, Бурханд залбирч, хаа сайгүй чуулгануудаар алхаж, ажил хийх явдал гэж боддог хүмүүс та нарын дунд олон бий. Бурханд үйлчлэх гэдэг нь хэзээ ч гэрлэхгүй, гэр бүлтэй болохгүй, өөрийгөө бүхэлд нь Бурханд зориулахын нэр гэж үздэг зарим ах эгч байдаг. Гэвч Бурханд үйлчлэх гэдэг нь үнэндээ юу гэсэн үг болохыг тун цөөхөн хүн л мэддэг. Хэдий тэнгэрийн од шиг олон хүн Бурханд үйлчилдэг боловч шууд үйлчилж чадах, мөн Бурханы хүслийн дагуу үйлчлэх чадвартай хүмүүсийн тоо шалихгүй—өчүүхэн бага. Яагаад Би ингэж хэлдэг вэ? Та нар “Бурханд үзүүлэх үйлчлэл” гэдэг үгийн мөн чанарыг ойлгодоггүй, Бурханы хүслийн дагуу яаж үйлчлэх талаар маш бага ойлгодог учраас Би ингэж хэлдэг. Бурханд үзүүлэх яг ямар үйлчлэл Түүний хүсэлд нийцэж чадах вэ гэдгийг хүмүүс нэн даруй ойлгох хэрэгтэй.

Хэрвээ та нар Бурханы хүсэлд нийцүүлж үйлчлэхийг хүсдэг бол ямар хүмүүсийг Бурхан таашаадаг, ямар хүмүүсийг Бурхан жигшдэг, ямар хүмүүсийг Бурхан төгс болгодог, мөн ямар хүн Бурханд үйлчлэх шаардлага хангадгийг эхлээд ойлгох ёстой. Энэ бол та нарын хамгийн наад захын мэдвэл зохих зүйл юм. Түүнээс гадна, та нар Бурханы ажлын зорилтуудыг, мөн одоо, энд хийх гэж байгаа Бурханы ажлыг мэдэх ёстой. Үүнийг ойлгосныхоо дараа, Бурханы үгийн удирдамжаар дамжуулан та нар эхлээд орж, Бурханы даалгаврыг хүлээн авах ёстой. Та нар Бурханы үгийн талаар бодит туршлагатай болмогцоо, мөн Бурханы ажлыг үнэхээр мэддэг болох үедээ Бурханд үйлчлэх шаардлагыг хангах болно. Та нарыг Бурханд үйлчлэх үед

Тэр сүнслэг нүдийг чинь нээж, Түүний ажлын тухай илүү их ойлголттой болж, илүү тодорхой харах боломжийг та нарт олгодог. Энэ бодит байдалд орох үед туршлага чинь илүү гүнзгий, бодит болж ийм туршлагатай хүн бүхэн чуулгануудаар алхаж, ах эгч нарыг тань хангаж чадна. Ингэснээр та нар нэг нь нөгөөгийнхөө давуу талаар дутагдлаа нөхөж, сүнсэндээ илүү баялаг мэдлэгийг олж авч чадна. Зөвхөн ийм үр дүнд хүрснийхээ дараа л та нар Бурханы хүсэлд нийцүүлэн үйлчлэх чадвартай болж, үйлчлэлийнхээ явцад Бурханаар төгс болгуулж чадна.

Бурханд үйлчилдэг хүмүүс нь Бурханы дотнын хүмүүс байх ёстой, тэд Бурханд таашаагдаж, Бурханд туйлын үнэнч байж чадах ёстой. Чи ганцаараа эсвэл олны өмнө үйлдсэн ч бай, Бурханы өмнө Бурханы баяр баяслыг олж авч, Бурханы өмнө бат зогсож чаддаг бөгөөд бусад хүн чамд хэрхэн хандахаас үл хамааран үргэлж алхах ёстой замаараа алхаж, Бурханы ачаанд бүхий л талаар санаа тавьдаг. Зөвхөн ийм л хүн Бурханы дотнын хүн юм. Бурханы дотнын хүмүүс Бурханы агуу даалгавар болон Бурханы ачааг авсан учир Түүнд шууд үйлчлэх чадвартай, Бурханы зүрх сэтгэлийг өөрийн болгож, Бурханы ачааг өөрийн болгож авах чадвартай бөгөөд хэтийн ирээдүйгээ эс хайхардаг. Тэд хэтийн ирээдүйгүй, юу ч олж авахгүй байсан ч хайрлах сэтгэлээр Бурханд үргэлж итгэх болно. Иймээс ч ийм хүн бол Бурханы дотнын хүн юм. Бурханы дотнын хүмүүс нь бас Түүний итгэлт хүмүүс юм; Бурханы итгэлт хүмүүс л Түүний санаа зовнил, бодлыг хуваалцаж чадна. Мөн махан бие нь өвдөж, сул дорой байсан ч Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд тэд хайрладаг зүйлээ орхиж, зовлон шаналлыг тэсэх чадвартай. Бурхан ийм хүмүүст илүү их ачаа өгдөг агаад Бурханы хийхийг хүсдэг зүйл ийм хүмүүсийн гэрчлэлээс төрөн гардаг. Иймийн учир энэ хүмүүс Бурханд таашаагддаг, тэд бол Бурханы Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух зарц нар нь бөгөөд ийм хүмүүс л Бурхантай хамт хаанчилж чадна. Чи үнэхээр Бурханы дотнын хүн болох яг тэр үе нь Бурхантай хамт хаанчлах үе байх болно.

Есүс өөртөө ямар нэг төлөвлөгөө гаргаж, зохицуулалт хийлгүйгээр Бурханы хүсэлд бүрэн санаа тавьсан учраас Бурханы даалгавар буюу бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлыг биелүүлэх чадвартай байсан. Тэрээр бас та бүхний маш сайн ойлгодог Бурханы дотнын хүн—Бурхан Өөрөө байсан. (Үнэндээ Тэр бол Бурханаар гэрчлэгдсэн Бурхан Өөрөө байсан; хэрэг явдлыг тайлбарлах үүднээс Би Есүсийн энэ баримтыг дурдав.) Тэрээр Бурханы удирдлагын төлөвлөгөөний ажлыг хамгийн голд нь тавьж чаддаг, үргэлж тэнгэрлэг Эцэгт залбирч, тэнгэрлэг Эцэгийн хүслийг эрж хайдаг байлаа. Тэрээр залбиран: “Эцэг Бурхан минь! Өөрийн хүслийг гүйцэлдүүлж, Миний хүслийн дагуу биш, Өөрийн төлөвлөгөөний дагуу үйлдээч. Хүн сул дорой байж болно, гэхдээ яагаад Та түүнд санаа тавих ёстой гэж? Таны алган дээрх шоргоолж шиг хүн яаж Таны анхаарал халамжийг хүртэх эрхтэй байж чадах юм бэ? Зүрх сэтгэлдээ Би зөвхөн Таны хүслийг гүйцэлдүүлэхийг л хүсэж байна, Та Өөрийн тааллаар Надад хийх зүйлээ хийгээсэй гэж Би хүсэж байна” гэсэн юм. Иерусалим руу явах замд Есүс яг л зүрхийг нь хутгаар сийчиж буй мэт шаналлыг

мэдэрч байсан ч үгнээсээ буцах өчүүхэн төдий ч санаа Түүнд байгаагүй; цовдлогдох газар луу нь нэгэн их хүч үргэлж Түүнийг түлхэж байв. Эцэст нь Тэр загалмайд цовдлогдож, нүгэлт махан биеийн төрхтэй болж, хүн төрөлхтнийг золин аврах ажлыг гүйцэлдүүлээд, үхэл хийгээд Үхэгсдийн орны дөнгөнөөс чөлөөлөгдсөн юм. Түүний өмнө үхэл, там, Үхэгсдийн орон хүч чадлаа алдаж, Түүнд ялагдсан билээ. Тэрээр гучин гурван жил амьдрах хугацаандаа тухайн үеийн Бурханы ажлын дагуу Бурханы хүслийг биелүүлэхийн тулд үргэлж чадах бүхнээ хийж, Өөрийн хувийн ашиг хонжоо, хохирлыг хэзээ ч бодож үзээгүй, Эцэг Бурханы хүслийг үргэлж бодож байсан. Иймээс Түүнийг баптисм хүртсэний дараа Бурхан: “Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг” гэж хэлсэн юм. Бурханы өмнөх Түүний үйлчлэл Бурханы хүсэлтэй нийцэж байсан учраас Бурхан бүх хүн төрөлхтнийг золин аврах хүнд хэцүү ачааг Түүнд үүрүүлж, Түүгээр гүйцэлдүүлсэн бөгөөд Тэрээр энэ чухал даалгаврыг биелүүлэх эрхтэй, шаардлага хангасан байв. Амьдралынхаа туршид Тэрээр Бурханы төлөө хэмжээлшгүй их зовлон туулж, тоо томшгүй олон удаа Сатаны сорилтод орсон боловч хэзээ ч мохоогүй. Бурхан Түүнд итгэж, Түүнийг хайрласан учраас ийм агуу даалгавар өгсөн, тиймээс ч Бурхан: “Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг” хэмээн Өөрөө хэлсэн билээ. Тухайн үед зөвхөн Есүс л энэхүү даалгаврыг биелүүлж чадах байсан агаад Нигүүлслийн эрин үед бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлаа Бурхан гүйцээсний нэг бодитой тал нь энэ байлаа.

Хэрэв та нар Есүс шиг Бурханы ачаанд бүхий л талаар санаа тавьж, махан биеэсээ татгалзаж чаддаг бол, Бурхан чухал даалгавраа та нарт даалгана, ингэснээр та нар Бурханд үйлчлэх нөхцөлийг хангах болно. Ийм нөхцөл байдалд л та нарыг Бурханы хүслийг гүйцэлдүүлж, Түүний даалгаврыг биелүүлж байна хэмээн хэлж зүрхэлнэ, тэр үед л та нар Бурханд үнэхээр үйлчилж байна гэж хэлж зүрхэлнэ. Есүсийн жишээтэй харьцуулбал чи өөрийгөө Бурханы дотнын хүн гэж хэлж зүрхлэх үү? Чи Бурханы хүслийг гүйцэлдүүлж байгаа гэж хэлж зүрхлэх үү? Чи үнэхээр Бурханд үйлчилж байна гэж хэлж зүрхлэх үү? Өнөөдөр чи Бурханд хэрхэн үйлчлэхээ мэддэггүй байж өөрийгөө Бурханы дотнын хүн гэж хэлж зүрхлэх үү? Чи Бурханд үйлчилдэг гэж хэлбэл Түүнийг доромжилж буй хэрэг биш гэж үү? Энэ тухай бодоод үзээрэй: Чи Бурханд үйлчилж байна уу, эсвэл өөртөө үйлчилж байна уу? Чи Сатанд үйлчилдэг атлаа Бурханд үйлчилж байгаа гэж зөрүүдлэн хэлснээрээ Бурханыг доромжилж байгаа хэрэг биш гэж үү? Миний ардуур олон хүн байр суурийн ашиг тусад шунаж, ховдоглон идэж, нойронд шимтэж, махан биедээ бүх анхаарлаа хандуулан, махан бие нь гарах гарцгүй болохоос үргэлж айдаг. Тэд зүй ёсны чиг үүргээ чуулганд биелүүлдэггүй, харин үнэгүй хооллож эсвэл ах эгч нараа Миний үгээр сургамжилж, эрх мэдлийн байр сууринаас бусдыг захирдаг. Энэ хүмүүс өөрсдийгөө Бурханы хүслийг биелүүлж байна гэж хэлсээр, үргэлж өөрсдийгөө Бурханы дотнын хүн гэж хэлдэг нь утгагүй хэрэг биш гэж үү? Хэрвээ санаа чинь зөв боловч Бурханы хүслийн дагуу үйлчлэх чадваргүй бол чи мунхаг

байна; харин санаа чинь буруу атал өөрийгөө Бурханд үйлчилж байна гэж хэлсээр байвал чи Бурханыг эсэргүүцдэг нэгэн тул Бурханд шийтгүүлэх учиртай! Би ийм хүмүүсийг огт өрөвддөггүй! Бурханы гэрт тэд үнэгүй хооллож, үргэлж махан биеийн тав тухад шунаж, Бурханы ашиг сонирхлыг хайхардаггүй; тэд үргэлж өөрсдөдөө сайн зүйлсийг эрж хайж, Бурханы хүсэлд ямар ч анхаарал хандуулдаггүй. Хийдэг бүхнийг нь Бурханы Сүнс шинжихийг тэд хүлээн зөвшөөрдөггүй. Тэд үргэлж ах эгч нараа залилж, мэхлэн, яг л усан үзмийн талбайг үргэлж гишгэчиж, усан үзэм хулгайлдаг үнэг шиг хоёр нүүртэй байдаг. Ийм хүмүүс Бурханы дотнын хүн байж чадах уу? Чи Бурханы ерөөлийг хүлээж авахад тохирно гэж үү? Өөрийн амь болон чуулганы төлөө ямар ч ачаа үүрдэггүй байж чи Бурханы даалгаврыг хүлээж авахад тохирно гэж үү? Чам шиг хүнд хэн итгэж зүрхлэх вэ? Чамайг ингэж үйлчилж байхад Бурхан чамд илүү том ажил даалгаж чадна гэж үү? Ажилд энэ нь садаа болох бус уу?

Бурханы хүсэлд нийцүүлэн үйлчлэхийн тулд ямар нөхцөлүүдийг биелүүлэх ёстойг та нарт мэдүүлэх гэж Би үүнийг хэлдэг. Хэрвээ та нар Бурханд зүрх сэтгэлээ өгдөггүй, Есүс шиг Бурханы хүсэлд бүхий л талаар санаа тавьдаггүй бол Бурханы итгэлийг олж чадахгүй, харин ч эцэстээ Бурханаар шүүгдэх болно. Магадгүй өнөөдөр ч гэсэн, Бурханд үйлчлэхдээ чи үргэлж Бурханыг мэхлэх санаа агуулж, Түүнд үргэлж хааш яаш хандаж байдаг. Товчхондоо, өөр юунаас ч үл хамааран хэрвээ чи Бурханыг хуурвал хахир хатуу шүүлт чам дээр ирнэ. Та нар Түүнд үйлчлэх зөв зам руу орсноор дамжуулан хоёргүй үнэнч сэтгэлээ Бурханд өгөх нь зүйтэй. Бурханы өмнө эсвэл бусад хүмүүсийн өмнө байгаа эсэхээс үл хамааран зүрх сэтгэл чинь үргэлж Бурханд хандаж байх ёстойн дээр чи Бурханыг яг л Есүс шиг хайрлахаар шийдсэн байх ёстой. Ийм маягаар Бурхан чамайг төгс болгож, ингэснээр чи Бурханы зүрх сэтгэлийн төлөө явдаг, Түүний зарц болно. Хэрвээ чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хүсэж, үйлчлэл чинь Түүний хүсэлд нийцэж байхыг хүсэж байвал Бурханд итгэх итгэлийн талаарх өмнөх үзэл бодлоо өөрчилж, Бурханд үйлчилж байсан хуучин арга барилаа өөрчлөх ёстой, ингэснээр чи Бурханаар илүү их төгс болгуулна. Ингэвэл Бурхан чамайг орхихгүй, мөн чи Петр шиг, Бурханыг хайрладаг хүмүүсийн тэргүүн эгнээнд байх болно. Хэрвээ чи гэмшихгүй хэвээр үлдвэл Иудас шиг төгсгөл чамд ирнэ. Бурханд итгэдэг бүх хүн үүнийг ойлгох ёстой.

БОДИТ БАЙДЛЫГ ХЭРХЭН МЭДЭХ ТУХАЙ

Бурхан бол бодитой Бурхан: Түүний бүх ажил бодитой, Түүний хэлдэг бүх үг бодитой, мөн Түүний илэрхийлдэг бүх үнэн бодитой. Түүний үг биш бүхэн утгагүй, оршин байдаггүй, ул үндэсгүй байдаг. Өнөөдөр Ариун Сүнс Бурханы үг рүү хүмүүсийг залж чиглүүлэх гэж байгаа. Хэрвээ хүмүүс бодит байдал руу орохоор эрэлхийлж байгаа бол бодит байдлыг эрж хайж, бодит байдлыг мэдэх ёстой, үүний

дараа тэд бодит байдалд туршлагажиж, бодит байдлыг амьдран харуулах ёстой. Хүмүүс бодит байдлыг хэдий чинээ их мэднэ, бусдын үг жинхэнэ эсэхийг төдий чинээ их таньж чаддаг; хүмүүс бодит байдлыг хэдий чинээ их мэднэ, төдий чинээ бага үзэлтэй байдаг; хүмүүс бодит байдалд хэдий чинээ их туршлагажна, бодитой Бурханы үйл хэргийг төдий чинээ их мэддэг ба завхарсан, сатанлаг зан чанараасаа салах нь тэдний хувьд төдий чинээ амархан байдаг; хүмүүс хэдий чинээ бодит байдалтай байна, Бурханыг төдий чинээ их мэдэж, махан биеийг төдий чинээ их жигшиж, үнэнийг хайрладаг; хүмүүс хэдий чинээ бодит байдалтай байна, Бурханы шаардлагын стандартад төдий чинээ дөхөж очдог. Бурханаар авхуулдаг хүмүүс бол бодит байдлыг эзэмшсэн, бодит байдлыг мэддэг, бодит байдалд туршлагажсанаар дамжуулан Бурханы бодит үйл хэргийг мэдэж авсан хүмүүс юм. Бурхантай бодитоор хамтран ажиллаж, биеэ сахилгажуулах тусмаа чи Ариун Сүнсний ажлыг төдий чинээ олж авч, бодит байдлыг төдий чинээ олж авч, мөн Бурханаар улам их гэгээрүүлэгдэж, улмаар Бурханы бодит үйл хэргийн талаарх мэдлэг чинь төдий чинээ ихэснэ. Хэрвээ чи Ариун Сүнсний одоогийн гэрэлд амьдарч чаддаг бол өнөөгийн хэрэгжүүлэлтийн зам чамд улам тодорхой болж, шашны үзэл болон өнгөрсөн үеийн хуучин хэрэгжүүлэлтээс өөрийгөө илүү сайн салгаж чадна. Өнөөдөр бодит байдал бол анхаарлын төв юм: Хүмүүс хэдий чинээ бодит байдалтай байна, үнэний тухай мэдлэг нь төдий чинээ тодорхой болж, Бурханы хүслийн талаарх ойлголт нь төдий чинээ ихэсдэг. Бодит байдал нь бүх бичиг үсэг, хоосон сургаалыг даван гарч чаддаг, бүх онол болон мэдлэгээс давж чаддаг ба хүмүүс бодит байдалд анхаарлаа төвлөрүүлэх тусам, Бурханыг төдий чинээ чин сэтгэлээсээ хайрлаж, Түүний үгээр өлсөж, цангадаг. Хэрвээ чи үргэлж бодит байдалд анхаарлаа төвлөрүүлдэг бол амьдралын гүн ухаан, шашны үзэл болон төрөлхийн зан авир чинь Бурханы ажлыг даган аяндаа арилна. Бодит байдлыг эрэлхийлдэггүй, бодит байдлын талаар ямар ч мэдлэггүй хүмүүс ер бусын зүйлсийн араас хөөцөлдөх талтай байдаг ба амархан мэхлэгдэнэ. Ариун Сүнс ийм хүмүүс дээр ажиллах ямар ч аргагүй байдаг тул тэдэнд хий хоосон, амьдрал нь ямар ч утгагүй санагддаг.

Чи үнэнийг хайхын төлөө бодитоор дадлагажиж, бодитоор хайж, бодитоор залбирч, зовохыг хүсэх үед л Ариун Сүнс чам дээр ажиллаж чадна. Үнэнийг эрж хайдаггүй хүмүүст бичиг үсэг, сургаал, хоосон онолоос өөр юу ч байдаггүй ба үнэнгүй хүмүүс угаасаа Бурханы талаар олон үзэлтэй байдаг. Иймэрхүү хүмүүс, Бурхан махан биеийг нь сүнслэг бие болгон өөрчилж, тэгснээр тэд гурав дахь тэнгэр өөд гарч магад гэж л хүсэн эрмэлзэж байдаг. Энэ хүмүүс хэчнээн мунхаг вэ! Ийм зүйл хэлдэг бүх хүн Бурханы талаар, эсвэл бодит байдлын талаар ямар ч мэдлэггүй байдаг; ийм хүмүүс Бурхантай хамтран ажиллах боломжгүй, харин зөвхөн идэвхгүйгээр л хүлээж чадна. Хэрвээ хүмүүс үнэнийг ойлгож, үнэнийг тодорхой харж, цаашлаад үнэнд орж, үүнийг хэрэгжүүлэхийг хүсвэл бодитоор дадлагажиж, бодитоор хайж, бодитоор өлсөж цангах ёстой. Өлсөж цангах үед чинь,

Бурхантай бодитоор хамтран ажиллах үед чинь Бурханы Сүнс гарцаагүй чамайг хөдөлгөж, чиний дотор ажиллана, энэ нь чамд илүү их гэгээрэл авчирч, бодит байдлын тухай илүү их мэдлэгийг өгч, аминд чинь асар тустай байх болно.

Хэрвээ хүмүүс Бурханыг мэдье гэвэл Бурхан бол бодитой Бурхан гэдгийг эхлээд мэдэх ёстой, түүнчлэн Бурханы үгийг, Бурханы махбод дахь бодит илрэлтийг болон Бурханы бодитой ажлыг мэдэх ёстой. Бурханы бүх ажил бодитой гэдгийг мэдсэнийхээ дараа л чи Бурхантай үнэхээр хамтран ажиллах чадна, энэ замаар л чи өөрийн амийг өсгөж чадна. Бодит байдлын талаар огт мэддэггүй бүх хүн Бурханы үгийг туулах ямар ч аргагүй байдаг ба тэд үзэлдээ баригдаж, төсөөлөл дотроо амьдардаг, тиймээс тэд Бурханы үгийн талаар ямар ч мэдлэггүй байдаг. Чи бодит байдлыг мэдэх тусмаа, Бурханд улам ойртож, Түүнтэй улам ойр дотно болно; чи тодорхойгүй байдал, хийсвэрлэл, хоосон сургаалыг эрж хайх тусмаа Бурханаас төдий чинээ холдож, улмаар Бурханы үгийг туулах нь хүнд бэрх, хэцүү гэдгийг, мөн орох чадваргүй гэдгээ төдий чинээ их мэдэрнэ. Хэрвээ чи Бурханы үгийн бодит байдалд орж, сүнслэг амьдралынхаа зөв замд орохыг хүсвэл эхлээд бодит байдлыг мэдэж, тодорхойгүй болон ер бусын зүйлсээс өөрийгөө салгах ёстой, өөрөөр хэлбэл, Ариун Сүнс чамайг дотроос чинь хэрхэн бодитоор гэгээрүүлж, залж чиглүүлдэг болохыг эхлээд ойлгох ёстой. Ийм маягаар, хүний доторх Ариун Сүнсний бодит ажлыг үнэхээр ухаарч чадвал чи Бурханаар төгс болгуулах зөв замд орсон байх болно.

Өнөөдөр бүх зүйл бодит байдлаас эхэлдэг. Бурханы ажил бол хамгийн бодит бөгөөд хүмүүсийн хүрч чадах зүйл; энэ бол хүмүүсийн туулж, биелүүлж чадах зүйл юм. Хүмүүст маш их тодорхойгүй, ер бусын зүйлс байдаг, эдгээр нь Бурханы одоогийн ажлыг мэдэхэд тэдэнд саад болдог. Тиймээс дадлага туршлагадаа тэд үргэлж хазайж, аливаа юмс хүнд хэцүү гэдгийг үргэлж мэдэрдэг ба эдгээр нь бүгд тэдний үзлээс болдог. Хүмүүс Ариун Сүнсний ажлын зарчмуудыг ухаарч чаддаггүй, бодит байдлыг мэддэггүй тул оролтын замдаа үргэлж сөрөг байдаг. Тэд Бурханы шаардлагуудыг алсаас хардаг ба тэдгээрийг биелүүлж чаддаггүй; тэд ердөө л Бурханы үг үнэхээр сайн гэдгийг хардаг боловч орох замыг олж чаддаггүй. Ариун Сүнс энэ зарчмаар ажилладаг: Хүмүүсийн хамтын ажиллагаагаар дамжуулан, мөн идэвхтэй залбирч, хайж, Бурханд ойртож байгаагаар дамжуулан үр дүнд хүрч чаддаг бөгөөд тэднийг Ариун Сүнс гэрэлтүүлж, гэгээрүүлж чаддаг. Ариун Сүнс ганцаараа үйлддэг, эсвэл хүн ганцаараа хийдэг юм биш. Хоёулаа зайлшгүй шаардлагатай бөгөөд хүмүүс хамтран ажиллаж, Бурханы шаардлагуудын стандартад хүрэхээр эрэлхийлэх тусам, Ариун Сүнсний ажил төдий чинээ их болдог. Ариун Сүнсний ажил дээр нэмээд хүмүүсийн бодит хамтын ажиллагаа байснаар л бодит туршлагуудыг болон Бурханы үгийн талаарх мөн чанарын мэдлэгийг бий болгож чадна. Аажмаар, ийм маягаар туршлагажсанаар л төгс хүн эцэстээ бий болно. Бурхан ер бусын зүйл хийдэггүй; хүмүүсийн үзлээр бол Бурхан төгс хүчит бөгөөд бүх зүйлийг Бурхан хийдэг—үүний үр дүнд хүмүүс идэвхгүйгээр

хүлээж, Бурханы үгийг уншдаггүй, эсвэл залбирдаггүй, ердөө Ариун Сүнс сэтгэлийг нь хөдөлгөхийг хүлээдэг. Харин зөв ойлголттой хүмүүс ингэж итгэдэг: Намайг хамтран ажиллахын хэрээр л Бурхан ажиллаж чадна. Бурханы ажлын надад үзүүлэх үр нөлөө хэрхэн хамтран ажиллахаас минь шалтгаалдаг. Бурханыг ярих үед Бурханы үгэнд шамдаж, эрж хайхын тулд би чадах бүхнээ хийх ёстой; энэ бол миний хийх ёстой зүйл.

Петр бодит байдалд хамгийн их анхаарал хандуулсныг та нар Петр, Паул хоёрын жишээнээс тодорхой харж болно. Петрийн туулсан зүйлээс, түүний туршлага нь өнгөрсөн цаг үеийн бүтэлгүйтсэн хүмүүсийн сургамжийг нэгтгэн дүгнэснийг, мөн тэрээр урьдын ариун хүмүүсийн давуу талыг шингээснийг харж болно. Үүнээс Петрийн туршлага хэр бодит байсныг, хүмүүс эдгээр туршлагад хандаж, хүрч, эдгээрийг биелүүлж чадна гэдгийг харж болно. Харин Паул өөр байсан: Түүний ярьсан бүхэн нь гурав дахь тэнгэр лүү явах, сэнтийд залрах, зөвт байдлын титэм гэх мэт тодорхойгүй, үл үзэгдэх зүйлс байв. Тэрээр байр суурь, хүмүүст зааж сургах, зэрэг зиндаагаа гайхуулах, Ариун Сүнсээр сэтгэлээ хөдөлгүүлэх гэх мэт гадаад талын зүйлсэд анхаарлаа төвлөрүүлсэн юм. Түүний эрэлхийлсэн юу ч бодит байгаагүй, ихэнх нь уран зөгнөл байсан, тиймээс Ариун Сүнс хүмүүсийг хэр их хөдөлгөдөг, хүмүүсийн эдэлдэг асар их баяр хөөр, гурав дахь тэнгэр лүү явах, эсвэл хүмүүсийн байнгын сургуулилт хийх дуртай байдаг хэр хэмжээ, Бурханы үгийг унших дуртай байдаг хэр хэмжээ гэх мэтийг бүгдийг нь ер бусын бүх зүйл гэж үзэж болно—эдгээрийн аль нь бодитой биш. Ариун Сүнсний бүх ажил хэвийн, бодит байдаг. Бурханы үгийг уншаад залбирах үедээ чи дотроо тогтвортой, гэрэлтэй байдаг бөгөөд гадаад дэлхий ертөнц чамд саад болж чадахгүй; чи дотроо Бурханыг хайрлахыг хүсэж, эерэг зүйлстэй харилцахыг хүсэж, ёрын муу ертөнцийг жигшдэг. Энэ бол Бурханы дотор амьдарч байгаа хэрэг юм. Энэ нь хүмүүсийн хэлдэг шиг асар их таашаал эдлэх явдал биш—иймэрхүү яриа нь бодитой биш. Өнөөдөр бүх зүйл бодит байдлаас эхлэх ёстой. Бурханы хийдэг бүхэн бодит бөгөөд туршлагаараа чи Бурханыг үнэхээр мэдэж, Бурханы ажлын мөр болон хүмүүсийг хөдөлгөж, гэгээрүүлдэг Ариун Сүнсний арга замд анхаарлаа хандуулах ёстой. Хэрвээ чи Бурханы үгийг ууж идэн, залбирч, илүү бодит байдлаар хамтран ажиллаж, Петрийн адилаар өнгөрсөн цаг үеийн сайныг шингээж, мууг нь голоод, мөн чихээрээ сонсож, нүдээрээ ажиглан, зүрх сэтгэлдээ үргэлж тунгаан бодож, залбирч, Бурханы ажилтай хамтран ажиллахын тулд чадах бүхнээ хийвэл Бурхан чамайг гарцаагүй залж чиглүүлнэ.

ХЭВИЙН СҮНСЛЭГ АМЬДРАЛЫН ТАЛААР

Бурханд итгэх итгэл нь Бурханы үгийг туулах, бодит байдалд орохын үндэс суурь болсон хэвийн сүнслэг амьдралыг шаарддаг. Та нарын залбирах, Бурханд ойртох, магтан дуу дуулах, магтах, бясалгах, Бурханы үгийг тунгаах одоогийн

хэрэгжүүлэлт “хэвийн сүнслэг амьдралтай” тэнцэх үү? Та нарын хэн нь ч мэдэхгүй юм шиг байна. Хэвийн сүнслэг амьдрал нь залбирах, магтан дуу дуулах, чуулганы амьдралд оролцох, Бурханы үгийг идэж, уух гэх мэт хэрэгжүүлэлтээр хязгаарлагддаггүй. Харин ч энэ нь шинэ, эрч хүчтэй сүнслэг амьдралаар амьдрахтай холбоотой. Хэрхэн хэрэгжүүлдэг чинь биш, харин хэрэгжүүлэлт чинь ямар үр дүнд хүрдэг нь чухал юм. Тийм хэрэгжүүлэлт үнэндээ ямар нэг үр нөлөөтэй эсэх, жинхэнэ ойлголтод хүргэдэг эсэхээс үл хамааран залбирах, магтан дуу дуулах, Бурханы үгийг идэж, уух, эсвэл тунгаан бодох нь хэвийн сүнслэг амьдралтай зайлшгүй холбоотой гэж ихэнх хүн итгэдэг. Ийм хүмүүс үр дүнг нь огтхон ч бодолгүйгээр өнгөц журмыг дагахад анхаардаг. Тэд бол шашны зан үйлэнд амьдардаг хүмүүс болохоос чуулган дотор амьдардаг хүмүүс биш бөгөөд хаанчлалын ардууд бүр ч биш юм. Тэдний залбирал, магтан дуу дуулах, Бурханы үгийг идэж, уух нь бүгд ердөө л шахалт шаардлагаар, чиг хандлагаас хоцрохгүйн тулд дүрэм журам дагаж байгаа болохоос дуртайяа, бас зүрх сэтгэлээсээ ч хийж байгаа биш юм. Энэ хүмүүс хэчнээн их залбирч, дуулсан ч хичээл зүтгэл нь ямар ч үр дүнгүй болно, учир нь тэдний хэрэгжүүлдэг зүйл нь ердөө л шашны зан үйл, дүрэм журам байдаг, тэд үнэндээ Бурханы үгийг хэрэгжүүлж байгаа юм биш. Тэд хэрхэн хэрэгжүүлж байгаагаа сүр болгоход л анхаардаг бөгөөд Бурханы үгийг дагаж мөрдөх дүрэм гэж авч үздэг. Ийм хүмүүс Бурханы үгийг хэрэгжүүлэхгүй байгаа, зүгээр л махан биеийн хүслийг хангаж, бусад хүмүүст харуулах гэж гүйцэтгэж байгаа. Эдгээр шашны дүрэм, зан үйл бүгд Бурханаас биш хүнээс гаралтай. Бурхан дүрэм дагадаггүй, ямар нэг хуульд ч захирагддаггүй. Харин ч Тэр өдөр бүр шинэ зүйл хийж, бодитой ажил бүтээдэг. Өдөр бүр өглөөний үйл ажиллагаанд оролцох, үдшийн залбирал болон хоолны өмнөх талархлын залбирал өргөх, бүх зүйлд талархах гэх мэт хэрэгжүүлэлтээр өөрсдийгөө хязгаарладаг Гурван-Өөрөө Сүмийн хүмүүс шиг тэд үүнийгээ хэчнээн их, хэчнээн удаан хийсэн ч тэдэнд Ариун Сүнсний ажил байхгүй байх болно. Хүмүүс дүрэм журам дунд амьдарч, зүрх сэтгэл нь хэрэгжүүлэлтийн арга барил дээр төвлөрсөн байх үед Ариун Сүнс ажиллаж чадахгүй, учир нь тэдний зүрх сэтгэл дүрэм журам, хүний үзлээр дүүрэн байдаг. Иймээс Бурхан хөндлөнгөөс оролцож, тэдэн дээр ажиллах боломжгүй байдаг ба тэд зөвхөн хууль дүрмийн хяналт дор үргэлжлүүлэн амьдарч л чадна. Ийм хүмүүс Бурханы магтаалыг хүртэж үүрд чадахгүй.

Хэвийн сүнслэг амьдрал бол Бурханы өмнө амьдарсан амьдрал юм. Залбирч байхдаа хүн Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж чадах бөгөөд залбирлаар дамжуулан Ариун Сүнсний гэгээрлийг эрж хайж, Бурханы үгийг мэдэж, Бурханы хүслийг ойлгож чадна. Бурханы үгийг идэж, ууснаар хүмүүс Бурханы одоогийн ажлын талаар илүү тодорхой, нарийн ойлголттой болж чадна. Тэд бас хэрэгжүүлэлтийн шинэ замыг олж авч чадах бөгөөд хуучинтай зууралдахгүй; тэдний хэрэгжүүлдэг бүхэн амийн өсөлтөд хүрэхийн төлөө байх болно. Залбирлын тухайд бол, хэчнээн өртэйгөө харуулахын тулд Бурханы өмнө сайхан сонсогддог

хэдхэн үгийг хэлэх, эсвэл цурхиран уйлах явдал биш; харин ч энэ нь, сүнсээ ашиглахад өөрийгөө сургаж, Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгах боломжтой байж, бүхий л хэрэг явдал дээр Бурханы үгээс удирдамж эрж хайхад өөрийгөө сургах зорилготой, ингэж гэмээ нь хүний зүрх сэтгэл өдөр бүр цоо шинэ гэрэл рүү ойртож чадна, мөн ингэж гэмээ нь хүн идэвхгүй, залхуу биш болж, Бурханы үгийг хэрэгжүүлэх зөв замд хөл тавьж чадна. Өнөөгийн ихэнх хүн хэрэгжүүлэлтийн арга барилд анхаардаг мөртөө үнэнийг эрэлхийлж, амийн өсөлтөд хүрэхэд анхаардаггүй. Тэд энд хазайсан юм. Шинэ гэрлийг хүлээн авах чадвартай зарим хүн мөн байдаг боловч тэдний хэрэгжүүлэлтийн арга барил өөрчлөгддөггүй. Тэд Бурханы өнөөдрийн үгийг хүлээж авахаар найдангаа хуучин шашны үзлээ байлгасаар байдаг, иймээс тэдний хүлээж авдаг зүйл нь шашны үзлээр будсан өнөө л сургаал байдаг, тэд өнөөдрийн гэрлийг зүгээр хүлээн авахгүй байгаа. Үр дүнд нь тэдний хэрэгжүүлэлт бохирддог, шинэ савлагаатай өнөө л хуучин хэрэгжүүлэлт хэвээр байдаг. Хэчнээн сайн хэрэгжүүлдэг байж болох ч тэд бол хоёр нүүртнүүд. Бурхан хүмүүсийг өдөр бүр шинэ зүйл хийхэд хөтөлж, өдөр бүр шинэ мэдлэг ухаан, ойлголт олж авахыг тэднээс нэхэж, хуучинсаг хийгээд давтагдмал бус байхыг шаарддаг. Хэрэв чи Бурханд олон жил итгэсэн хэдий ч хэрэгжүүлэлтийн арга барил чинь огтхон ч өөрчлөгдөөгүй бол, гадаад хэрэг явдалд улайран, хамаг анхаарлаа хандуулсаар байгаа хэдий ч Бурханы үгийг эдлэхийн тулд Түүний өмнө тайван зүрх сэтгэлтэй байдаггүй бол чи юу ч олж авахгүй. Бурханы шинэ ажлыг хүлээн авах тал дээр, хэрэв өөрөөр төлөвлөхгүй, хэрэгжүүлэлтээ шинэ арга замаар гүйцэтгэхгүй, шинэ ойлголтуудыг эрэлхийлэхгүй, харин хуучинтайгаа зууралдаж, хэрэгжүүлэлтийн арга замаа өөрчлөхгүйгээр шинэ гэрлийг хагас хугасхан хүлээж авдаг бол та нар шиг ийм хүмүүс энэ урсгалд нэр төдий байдаг. Бодит байдал дээр тэд бол Ариун Сүнсний урсгалын гаднах шашны фарисайчууд юм.

Хэвийн сүнслэг амьдралаар амьдрахын тулд хүн шинэ гэрлийг өдөр бүр хүлээн авч, Бурханы үгийн талаарх жинхэнэ ойлголтыг эрэлхийлж чаддаг байх ёстой. Хүн үнэнийг тодорхой харж, бүх хэрэг явдалд хэрэгжүүлэлтийн замыг олж, Бурханы үгийг өдөр бүр уншсанаар шинэ асуултуудыг олж илрүүлж, хангалтгүй байдлаа ухаарах ёстой. Ингэж гэмээ нь хүн өөрийнх нь бүхий л оршихуйг хөдөлгөдөг хүсэн тэмүүлж, эрж хайдаг зүрх сэтгэлтэй байх боломжтой ба ингэж гэмээ нь магадгүй хүн Бурханы өмнө цаг үргэлж тайван байж, хоцорч үлдэхээс ихэд эмээнэ. Тасралтгүй оролтод хүрэхийг хүсдэг, хүсэн тэмүүлж, эрж хайдаг ийм зүрх сэтгэлтэй хүн сүнсний амьдралын зөв зам дээр байна. Ариун сүнсэнд сэтгэл нь хөдөлдөг, илүү сайн хийхийг хүсдэг, Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлэхэд бэлэн, Бурханы үгийг гүнзгий ойлгохоор хүсэн тэмүүлдэг, ер бусын зүйлийг эрэлхийлдэггүй, харин бодит төлөөс төлдөг, Бурханы хүсэлд үнэхээр санаа тавьдаг, туршлагаа илүү жинхэнэ, бодитой болгохын тулд үнэхээр оролтод хүрдэг, хоосон үг, сургаалыг эрэлхийлдэггүй эсвэл ер бусын зүйлийг мэдрэх гэж

эрэлхийлдэггүй, аливаа нэг агуу хүнийг шүтдэггүй ийм хүмүүс нь хэвийн сүнслэг амьдралд орсон хүмүүс юм. Тэдний хийдэг бүхэн цаашдын амийн өсөлтөд хүрч, сүнсэндээ өөрсдийгөө шинэлэг, эрч хүчтэй болгох зорилготой бөгөөд тэд идэвхтэйгээр оролтод хүрч үргэлж чаддаг. Тэд өөрсдөө мэдэлгүй үнэнийг ойлгож, бодит байдалд ордог. Хэвийн сүнслэг амьдралтай хүмүүс өдөр бүр сүнсний чөлөөлөлт, эрх чөлөөг олдог ба тэд Бурханыг сэтгэл хангалуун байлгах хэмжээнд чөлөөтэй байдлаар Түүний үгийг хэрэгжүүлж чадна. Энэ хүмүүсийн хувьд залбирах нь тогтсон дүрэм, эсвэл журам биш юм. Тэд өдөр бүр шинэ гэрэлтэй хөл нийлүүлэн алхаж чаддаг. Жишээлбэл, хүмүүс Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгахад өөрсдийгөө сургадаг бөгөөд тэдний зүрх сэтгэл Бурханы өмнө үнэхээр тайван байж чаддаг, хэн ч тэднийг үймүүлж чаддаггүй. Ямар ч хүн, үйл явдал, зүйл тэдний хэвийн сүнслэг амьдралыг хязгаарлаж чадахгүй. Ийм сургуулилт нь үр дүн гаргахад чиглэсэн байдаг болохоос хүмүүсийг дүрэм дагадаг болгоход чиглэдэггүй. Энэ хэрэгжүүлэлт нь дүрэм дагах биш, харин хүмүүсийн амийн өсөлтийг дэмжихийн төлөө байдаг. Хэрэв чи энэ хэрэгжүүлэлтийг мөрдөх дүрэм л гэж харвал амь чинь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Чи магадгүй бусадтай адилхан хэрэгжүүлж болох ч эцсийн дүнд тэд Ариун Сүнсний ажилтай мөр зэрэгцэн алхаж чадаж байхад чи Ариун Сүнсний урсгалаас таягддан хаягддаг. Чи өөрийгөө хуурч байгаа бус уу? Эдгээр үг нь хүмүүст Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж, зүрх сэтгэлээ Бурханд хандуулах боломж олгох зорилготой, тэгж гэмээ нь тэдэнд хийх Бурханы ажил саадгүй байж, үр дүнд хүрч болох юм. Тэр үед л хүмүүс Бурханы хүсэлд нийцэж чадна.

ЧУУЛГАНЫ АМЬДРАЛ БА БОДИТ АМЬДРАЛЫГ ХЭЛЭЛЦЭХ НЬ

Чуулганы амьдрал дотор л өөрчлөгдөж чадна гэж хүмүүст санагддаг. Чуулган дотор амьдрахгүй бол өөрчлөгдөж чадахгүй, бодит амьдрал дээр өөрчлөлтөд хүрэх боломжгүй мэт тэдэнд санагддаг. Энд асуудал юу байгааг та нар ойлгож байна уу? Бурханыг бодит амьдралд авчрах талаар өмнө нь Би ярьсан; энэ бол Бурханд итгэдэг хүмүүс Бурханы үгийн бодит байдал руу орох зам билээ. Үнэндээ чуулганы амьдрал бол хүмүүсийг төгс болгох хязгаарлагдмал арга зам төдий юм. Хүмүүсийг төгс болгох үндсэн орчин нь ямар ч гэсэн бодит амьдрал билээ. Энэ нь Миний ярьсан бодит хэрэгжүүлэлт, бодит дадлага бөгөөд өдөр тутмын амьдралдаа хэвийн хүн чанарын амьдралд хүрч, жинхэнэ хүний төрхийг амьдран харуулах боломжийг хүмүүст олгодог. Нэг талаар, хүн боловсролын түвшнээ дээшлүүлэх, Бурханы үгийг ойлгох ба хүлээн авах чадвартай болохын тулд сурч боловсрох ёстой. Нөгөө талаар, хэвийн хүн чанарын ухаарал болон эрүүл ухааныг олж авахын тулд хүн шиг амьдрахад шаардлагатай суурь мэдлэгээр зэвсэглэсэн байх ёстой,

учир нь хүмүүс энэ талууд дээр бараг юу ч үгүй байдаг. Үүнээс гадна, хүн бас чуулганы амьдралаар дамжуулан Бурханы үгийг амталж, аажмаар үнэний тухай тодорхой ойлголттой болох ёстой.

Бурханд итгэхдээ Бурханыг бодит амьдралд авчрах ёстой гэж яагаад хэлдэг вэ? Хүмүүсийг өөрчилдөг нь зөвхөн чуулганы амьдрал биш; илүү чухал нь хүн бодит амьдралд бодит байдал руу орох ёстой. Та нар сүнслэг байдал, сүнслэг асуудлуудынхаа талаар өмнө нь байнга ярьдаг байсан хэрнээ бодит амьдралд олон зүйлийг хэрэгжүүлэлгүй орхиж, мөн тэдгээрт орохоо үл хайхардаг байсан. Та нар өдөр бүр бичиж, өдөр алгасалгүй сонсож, уншдаг байсан. Хоолоо хийж байхдаа “Өө, Бурхан! Та миний доторх амь болох болтугай. Өнөөдөр яаж өнгөрсөн ч намайг ерөөж, гэгээрүүлээч. Та өнөөдөр намайг юуны ч талаар гэгээрүүлсэн бай, үүнийг яг одоо ойлгох боломж надад өгөөч, ингэснээр Таны үг миний амь болж магадгүй” гэж хүртэл залбирсан. Хоолоо идэж байхдаа бас: “Өө, Бурхан минь! Та энэ хоолыг бидэнд хайрласан билээ. Та биднийг ерөөх болтугай. Амен! Амьдралынхаа төлөө Танд найдахыг зөвшөөрөөч. Та бидэнтэй хамт байх болтугай. Амен!” гэж залбирсан. Хоолоо идэж дуусаад аяга тавгаа угааж байхдаа “Өө, Бурхан минь, би бол энэ аяга. Сатан биднийг завхруулж, бид яг л усаар цэвэрлэх ёстой хэрэглэсэн аяга шиг болжээ. Та бол ус, Таны үг бол амийг минь тэтгэгч амьд ус билээ” гэж дэмийрч эхэлсэн. Нэг л мэдэхэд унтах цаг болж, “Өө, Бурхан минь! Та намайг өдөржин ерөөж, чиглүүллээ. Би Танд үнэхээр их талархаж байна …” хэмээн дахиад дэмийрч эхэлсэн. Энэ маягаар чи өдрийг өнгөрүүлж, дуг нойрондоо умбасан. Ихэнх хүн өдөр бүр энэ маягаар амьдарсан ба одоо ч гэсэн бодит оролтоо хайхрахгүй, харин амаараа залбирахад л анхаарсан юм. Энэ бол тэдний урьдын амьдрал—хуучин амьдрал нь. Ихэнх нь ийм; ямар нэгэн бодит дадлагаар дутмаг бөгөөд тун цөөхөн бодит өөрчлөлт амсдаг. Тэд зөвхөн амаараа залбирч, зөвхөн үгээрээ Бурханд ойртох боловч ойлголт нь гүнзгий биш байдаг. Хамгийн энгийн жишээ болгож гэрээ цэвэрлэхийг авч үзье. Чи гэрээ замбараагүй байгааг харж, тэндээ суугаад: “Өө, Бурхан минь! Сатаны надад нөлөөлсөн ялзралыг хараач. Би яг л энэ гэр орон шиг бохир заваан юм. Өө, Бурхан минь! Би Таныг үнэхээр магтаж, Танд талархъя. Таны аврал, гэгээрэлгүйгээр би энэ баримтыг ойлгохгүй байх байсан” хэмээн залбирдаг. Чи зүгээр тэнд сууж, дэмий үглээд л удаан хугацаанд залбираад дараа нь юу ч болоогүй юм шиг авирлаж, үглээ эмгэн шиг аашилдаг. Чи энэ маягаар бодит байдалд жинхэнээсээ огтхон ч оролгүй, хэтэрхий олон өнгөц хэрэгжүүлэлттэйгээр сүнслэг амьдралаа өнгөрүүлдэг! Бодит дадлагад орох нь хүмүүсийн бодит амьдрал, бодитой бэрхшээлийг хамардаг—энэ бол тэднийг өөрчлөх цорын ганц зам юм. Бодит амьдралгүйгээр хүмүүс өөрчлөгдөж чадахгүй. Амаараа залбирахын хэрэг юу вэ? Хүний уг чанарыг ойлгохгүй бол бүх зүйл цагийн гарз, хэрэгжүүлэх замгүй бол бүх зүйл дэмий л хүчээ барсан хэрэг юм! Хэвийн залбирал хүмүүсийн доторх хэвийн байдлыг хадгалж чаддаг ч тэднийг бүр өөрчилж чадахгүй. Хүний өөрийгөө зөвтгөдөг, сагсуу, биеэ тоосон, дээрэлхүү байдлыг

мэдэх, мөн завхарсан зан чанарыг мэдэх нь—эдгээр зүйлийн талаарх мэдлэг нь—залбирлаар ирдэггүй, харин Бурханы үгийг амталснаар тэдгээрийг нээн илрүүлэх ба бодит амьдралд Ариун Сүнсний гэгээрлээр дамжуулан мэддэг. Өнөөгийн хүмүүс бүгдээрээ аман дээрээ нэлээд сайхан ярьж чаддаг бөгөөд хамгийн өндөр—үе үеийн бусад ямар ч номлолоос өндөр—номлол сонссон хэрнээ түүнээс маш багыг амьдралдаа хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, тэдний бодит амьдралд Бурхан үгүй; өөрчлөлтийн дараах шинэ хүний амьдрал тэдэнд байдаггүй. Бодит амьдралд үнэнийг амьдран харуулдаггүй, мөн бодит амьдралд Бурханыг авчирдаггүй. Тэд тамын хөвгүүд шиг амьдардаг. Энэ нь увайгүй гажуудал биш гэж үү?

Хэвийн хүний төрхийг сэргээх буюу хэвийн хүн чанартай болохын тулд хүмүүс зөвхөн үгээрээ Бурханыг баярлуулж болохгүй. Ингэснээрээ тэд өөрсдийгөө хорлодог бөгөөд энэ нь тэдний оролт болон өөрчлөлтөд ямар ч ашиг тусгүй. Тиймээс өөрчлөлтөд хүрэхийн тулд хүмүүс бага багаар хэрэгжүүлэх ёстой. Тэд алгуурхнаар орж, жаахан жаахнаар эрж хайж, шинжилж, эерэг талаас орж, үнэний бодит амьдралаар, ариун хүний амьдралаар амьдрах ёстой. Тэгсний дараа бодит асуудал, бодит зүйлс, бодит орчин нь хүмүүст бодит дадлагатай болох боломж олгодог. Тэднээс хоосон ярихыг шаарддаггүй; харин бодит орчинд дадлага хийхийг шаарддаг. Хүмүүс эхлээд дорд хэв чанартайгаа ухаарч, дараа нь Бурханы үгийг хэвийн байдлаар идэж, уун, хэвийн орж, бас хэвийн хэрэгжүүлдэг; ингэж тэд бодит байдлыг олж авдаг ба ийнхүү оролт нь илүү хурдацтай явагдаж болох юм. Хүмүүсийг өөрчлөхийн тулд зарим нэг бодит байдал байх ёстой; тэд бодит зүйл, бодит үйл явдал, бодит орчинтойгоор хэрэгжүүлэх ёстой. Чуулганы амьдралд түшиглэх төдийхнөөр жинхэнэ дадлага олж чадах уу? Хүмүүс бодит байдалд ингэж орж чадах уу? Үгүй! Хэрвээ хүмүүс бодит амьдралд орж чадахгүй бол хуучин амьдралын хэв маяг, аливааг хийдэг арга замаа өөрчилж чадахгүй. Энэ нь бүхэлдээ хүний залхуурал, хэт их найдамтгай зангаас болдоггүй, харин ердөө л хүн амьдрах чадамжгүйгээс, түүнчлэн Бурханы шаарддаг хэвийн хүний төрхийн стандартыг ойлгодоггүйгээс болдог. Урьд нь хүмүүс байнга хэлж, ярьж, нөхөрлөж, бүр “уран илтгэгч” болж байсан атлаа тэдний нэг нь ч амь зан чанартаа өөрчлөлт эрж хайж байгаагүй; харин тэд гүн гүнзгий онол эрж хайх гэж сохроор зүтгэсэн. Тиймээс өнөөгийн хүмүүс амьдралдаа Бурханд итгэх шашны энэ маягийг өөрчлөх ёстой. Тэд нэг зүйл, нэг үйл явдал, нэг хүн дээр анхаарлаа төвлөрүүлэн хэрэгжүүлэлт рүү орох ёстой. Тэд аливааг анхааралтай хийх ёстой—тэр үед л үр дүнд хүрч чадна. Хүмүүсийн өөрчлөлт мөн чанараас нь эхэлдэг. Уг ажил хүмүүсийн мөн чанар, амьдрал болон залхуу хойрго, найдамтгай зан, боол шиг байдалд чиглэх ёстой, тэгж байж л тэд өөрчлөгдөж чадна.

Хэдий чуулганы амьдрал зарим талаараа үр дүнтэй байж болох ч гол нь бодит амьдрал хүнийг өөрчилж чаддаг. Бодит амьдралгүйгээр хүний хуучин уг чанарыг өөрчилж чадахгүй. Нигүүлслийн эрин үе дэх Есүсийн ажлыг жишээ болгон авч үзэцгээе. Есүс хуучин хуулиудыг халж, шинэ эрин үеийн тушаалуудыг тогтоохдоо

бодит амьдралын жинхэнэ жишээ ашиглан ярьсан билээ. Нэгэн амралтын өдөр Есүс шавь нараа дагуулан тариан талбай дундуур явахад шавь нар нь өлсөж, тариан түрүү идэх гээд шувтрав. Үүнийг фарисайчууд хараад амралтын өдрийг сахисангүй гэцгээжээ. Тэд бас амралтын өдөр ямар ч ажил хийж болохгүй гэцгээж, амралтын өдөр нүхэнд унасан тугалуудыг аварч болохгүй хэмээсэн юм. Есүс эдгээр явдлыг эш татан шинэ эрин үеийн тушаалуудыг аажмаар тунхаглажээ. Тухайн үед хүмүүст ойлгуулж, мөн өөрчлөгдөхөд нь туслахын тулд Тэр олон бодит явдлыг ашигласан. Энэ нь Ариун Сүнс ажлаа гүйцэтгэдэг зарчим бөгөөд зөвхөн ийм маягаар л хүмүүсийг өөрчилж чадна. Бодит явдал байхгүй бол хүмүүс зөвхөн онол, оюун ухааны ойлголт олж авч чадна—энэ бол өөрчлөх үр дүнтэй арга биш юм. Тэгэхээр, мэргэн ухаан, ухаарлыг дадлагаар хэрхэн олж авдаг вэ? Хүн зүгээр л сонсож, уншиж, мэдлэгээ сайжруулснаар мэргэн ухаан, ухаарал олж авч чадах уу? Яаж ийм байж болох билээ? Хүн бодит амьдралд ойлгож, туулах ёстой! Тиймээс хүн дадлага хийх ёстой бөгөөд бодит амьдралаас холдох ёсгүй. Хүмүүс өөр өөр талуудад анхаарал хандуулж, янз бүрийн талд: хүний боловсролын түвшин, илэрхийлэх байдал, аливааг харах чадвар, ялган таних, Бурханы үгийг ойлгох чадвар, суурь мэдлэг, хүн чанарын ёс журам болон хүмүүст байвал зохих хүн чанартай холбоотой бусад зүйлд орох ёстой. Ойлголт олж авсныхаа дараа хүмүүс оролтдоо анхаарах ёстой ба тэр үед л өөрчлөлтөд хүрч чадна. Хүн ойлголт олж авсан хэрнээ хэрэгжүүлэлтийг орхисон бол яаж өөрчлөгдөж чадах юм бэ? Одоо хүмүүс ихийг ойлгодог боловч бодит байдлыг амьдран харуулдаггүй; тийм учраас Бурханы үгийн мөн чанарын талаар баттай ойлголт бага байдаг. Чи ердөө бага зэрэг л гэгээрсэн; Ариун Сүнснээс жаахан гэрэлтүүлэлт хүлээн авсан мөртөө бодит амь руу ордоггүй—эсвэл оролтын талаар огт тоодоггүй—тул өөрчлөлт чинь багасна. Тийм урт хугацааны дараа хүмүүс ихийг ойлгож байна. Онолын мэдлэгийнхээ тухай ихийг ярьж чаддаг боловч гаднах зан чанар нь хэвээр үлдэж, анхдагч хэв чанар нь өчүүхэн ч сайжралгүй байсан шигээ үлддэг. Хэрвээ тийм бол чи эцэстээ хэзээ орох юм бэ?

Чуулганы амьдрал бол хүмүүс Бурханы үгийг амтлах гэж цугладаг ердөө л нэг төрлийн амьдрал бөгөөд хүний амьдралын өчүүхэн хэлтэрхий төдий юм. Хэрвээ хүний бодит амьдрал бас чуулганы амьдралтай нь адил—хэвийн сүнслэг амьдралтай, Бурханы үгийг хэвийн байдлаар амталдаг, хэвийн байдлаар Бурханд залбирч, Түүнтэй ойр байдаг, Бурханы хүслийн дагуу бүхнийг үйлддэг бодит амьдралтай, үнэний дагуу бүгдийг үйлддэг бодит амьдралтай, залбирал үйлдэж, Бурханы өмнө тайван байдаг, магтан дуу дуулж, бүжиглэдэг бодит амьдралтай—бол зөвхөн тийм амьдрал л хүнийг Бурханы үгийн амьдрал руу аваачна. Ихэнх хүн чуулганы амьдралынхаа хэдэн цагаас бусад үеийн амьдрал нь огт хамаагүй мэт “тоохгүйгээр” зөвхөн тэр хэдэн цагт анхаарлаа төвлөрүүлдэг. Мөн Бурханы үгийг идэж ууж, магтан дуу дуулж, залбирч байхдаа л ариун хүний амьдрал руу ороод бусад цагт нь хуучин байдалдаа эргэн очдог олон хүн байдаг. Тийм амьдрал

хүмүүсийг өөрчилж чаддаггүй, Бурханыг мэдэх боломж бүр ч өгөхгүй. Хүн Бурханд итгэхдээ, өөрийн зан чанарыг өөрчлөхийг хүсвэл өөрийгөө бодит амьдралаас салгах ёсгүй. Чи бодит амьдралд өөрийгөө мэдэж, өөрийгөө хаяж, үнэнийг хэрэгжүүлж, түүнчлэн бүх зүйл дээр биеэ авч явах зарчмууд, суурь мэдлэг, ёс журмыг суралцах ёстой, ингэсний дараа чи аажмаар өөрчлөгдөж чадна. Хэрвээ чи бодит байдалд гүн нэвтрэхгүйгээр, бодит амьдралд орохгүйгээр зөвхөн онолын мэдлэгт анхаарч, шашны зан үйл дунд амьдарвал бодит байдалд хэзээ ч орохгүй, өөрийгөө, үнэнийг, Бурханыг хэзээ ч мэдэхгүй, үргэлж сохор, мэдлэггүй байх болно. Хүмүүсийг аврах Бурханы ажил нь хүнийг богинохон хугацаанд хэвийн хүний амьдралаар амьдруулах явдал биш, эндүү ташаа үзэл, хоосон сургаалыг нь өөрчлөх явдал ч биш. Харин хүмүүсийн хуучин зан чанарыг өөрчлөх, амьдралын хуучин маягийг нь тэр чигт нь өөрчлөх, бүх хоцрогдсон сэтгэлгээ, сэтгэл санааны байдлыг өөрчлөх нь Түүний зорилго юм. Зөвхөн чуулганы амьдралд анхаарснаар хүний амьдралын хуучин зуршил, эсвэл урт удаан хугацаанд амьдарч ирсэн хуучин маягийг өөрчлөхгүй. Ямар ч атугай, хүн бодит амьдралаас тасарч болохгүй. Хэвийн хүн чанарыг зөвхөн чуулганы амьдралд төдийгүй бодит амьдралд амьдран харуулахыг; үнэнийг зөвхөн чуулганы амьдралд төдийгүй бодит амьдралд амьдран харуулахыг; өөрсдийн чиг үүргийг зөвхөн чуулганы амьдралд төдийгүй бодит амьдралд гүйцэтгэхийг Бурхан хүмүүсээс хүсдэг. Бодит байдалд орохдоо хүн бүх зүйлийг бодит амьдрал руу хандуулах ёстой. Хэрвээ хүмүүс Бурханд итгэхдээ, бодит амьдралд орсноор дамжуулан өөрсдийгөө мэдэж чадахгүй бол, мөн бодит амьдрал дээр хэвийн хүн чанарыг амьдран харуулж чадахгүй бол бүтэлгүй хүмүүс болно. Бурханд дуулгаваргүй хүмүүс нь бүгдээрээ бодит амьдралд орж чаддаггүй хүмүүс юм. Тэд бүгдээрээ хүн чанарын талаар ярьдаг мөртөө чөтгөрийн уг чанарыг амьдран харуулдаг хүмүүс юм. Тэд бол бүгдээрээ үнэний тухай ярьдаг мөртөө хоосон сургаалыг амьдран харуулдаг хүмүүс юм. Бодит амьдралд үнэнийг амьдран харуулж чаддаггүй хүмүүс бол Бурханд итгэдэг ч Түүнд жигшигдэн гологддог хүмүүс билээ. Чи бодит амьдралд оролтоо хэрэгжүүлж, өөрийн дутагдал, дуулгаваргүй болон мунхаг байдал, хэвийн бус хүн чанар, сул талыг мэдэх ёстой. Ийм маягаар мэдлэг чинь чиний бодит нөхцөл байдал, бодит бэрхшээлтэй нэгдэнэ. Ийм төрлийн мэдлэг л бодит бөгөөд байр байдлаа бүрэн ухамсарлаж, зан чанарын өөрчлөлтөд хүрэх боломжийг чамд олгож чаддаг.

Хүмүүсийг төгс болгох явдал одоо албан ёсоор эхэлчихсэн, чи бодит амьдралд орох ёстой. Тиймээс өөрчлөлтөд хүрэхийн тулд бодит амьдралд орохоос эхэлж, бага багаар өөрчлөгдөх ёстой. Хэрвээ чи хүний хэвийн амьдралаас зайлсхийж, сүнслэг асуудлын талаар л яривал юмс сонирхолгүй, уйтгартай болно; тэдгээр нь бодит бус болно, тэгээд хүн яаж өөрчлөгдөж чадах юм бэ? Бодитой туршлага руу орох үндэс суурийг тавихын тулд бодит амьдралд хэрэгжүүлэхээр ор гэж одоо чамд хэлсэн. Энэ бол хүний хийх ёстой зүйлсийн нэг мөн. Ариун Сүнсний ажил бол голдуу удирдах байдаг бол харин үлдсэн хэсэг нь хүмүүсийн хэрэгжүүлэлт болон

оролтоос хамаардаг. Хүн бүр янз бүрийн замаар бодит амьдрал руу орж болно, тэгснээрээ бодит амьдралд Бурханыг авчирч, жинхэнэ хэвийн хүн чанарыг амьдран харуулж чадна. Энэ л утга учиртай амьдрал юм!

ХҮН БҮР ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ

Одоогийн урсгалд, Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг хүн бүхэнд Бурханаар төгс болгуулах боломж бий. Хөгшин залуу байх нь хамаагүй, зүрх сэтгэлдээ Бурханд дуулгавартай байж, Түүнийг хүндэлж байгаа цагт Бурханаар төгс болгуулж чадна. Бурхан хүмүүсийг өөр өөр чиг үүргийнх нь дагуу төгс болгодог. Тиймээс бүх хүчээ дайчилж, Бурханы ажилд захирагдаж байгаа цагт Тэр чамайг төгс болгож чадна. Одоогоор та нарын хэн нь ч төгс биш. Заримдаа та нар нэг төрлийн үүрэг гүйцэтгэж, харин зарим үед хоёрыг гүйцэтгэж чаддаг. Бурханы төлөө өөрийгөө зарлагадахад чадах бүхнээ хийж л байгаа цагт Тэр чамайг эцэст нь төгс болгоно.

Залуу хүмүүс амьдралын гүн ухаан арай багатай, мэргэн ухаан, мэдлэг ухаанаар дутмаг байдаг. Бурхан хүний мэргэн ухаан, мэдлэг ухааныг төгс болгохын тулд энд ирдэг ба Түүний үг хүмүүсийн дутагдлыг нөхдөг. Гэхдээ залуу хүмүүсийн зан чанар тогтворгүй байдаг бөгөөд Бурхан үүнийг өөрчлөх шаардлагатай. Залуу хүмүүс шашны үзэл, амьдралын гүн ухаан арай багатай байдаг. Тэд бүх зүйлийг энгийнээр сэтгэдэг бөгөөд бодож эргэцүүлдэг зүйл нь ярвигтай биш. Энэ бол тэдний хүн чанарын хараахан төлөвшөөгүй бөгөөд бас сайшаалтай тал боловч тэд мэдлэггүй, мэргэн ухаанаар дутмаг байдаг. Энэ бол Бурханы төгс болгох хэрэгтэй зүйл юм. Бурханаар төгс болгуулснаар та нар ялган таних чадварыг хөгжүүлэх боломжтой болдог. Олон сүнслэг зүйлийг тодорхой ойлгох чадвартай болж, аажмаар Бурхан ашиглахад тохиромжтой нэгэн болдог. Насаар ахмад ах эгч нарт ч бас өөрийн гэсэн гүйцэтгэх үүрэг байдаг бөгөөд Бурхан тэднийг орхиогүй. Ахмад ах, эгч нарт ч гэсэн хүсүүштэй болон хүсэмгүй талууд бий. Тэд илүү их амьдралын гүн ухаан, шашны үзэлтэй байдаг. Тэд үйлдэлдээ хатуу чанд олон ёс журмыг баримталж, аливаа дүрэм журмыг уян хатан бус механикаар хэрэгжүүлэх дуртай байдаг нь тэдний хүсэмгүй тал юм. Гэхдээ энэ ахмад ах эгч нар юу ч тохиолдсон тайван, тууштай хэвээр байдаг; зан чанар нь тогтвортой, догшин ширүүн ааш байдаггүй. Тэд аливааг хүлээн зөвшөөрөхдөө арай удаан байж болох ч энэ нь том дутагдал биш юм. Та нар захирагдаж чаддаг л бол, Бурханы одоогийн үгийг хүлээн зөвшөөрч чаддаг бөгөөд Бурханы үгийг шинжилдэггүй л бол, зөвхөн захирагдаж, дагах талаар л санаа тавьдаг бөгөөд Бурханы үгийг хэзээ ч шүүмжилдэггүй, тэдгээрийн талаар өөр бусад муу бодол өвөрлөдөггүй л бол, Түүний үгийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлдэг л бол—ийнхүү эдгээр нөхцөлийг хангаснаараа та нар төгс болгуулж чадна.

Насаар залуу эсвэл ахмад ах эгч нар байна уу хамаагүй, та нар гүйцэтгэх ёстой чиг үүргээ мэддэг. Залуу хүмүүс биеэ тоодоггүй; ахмад хүмүүс нь идэвхгүй биш бөгөөд ухарч буцдаггүй. Түүнчлэн тэд бие биеийнхээ давуу талаар сул талаа нөхөж, ямар ч өрөөсгөл хандлагагүйгээр нэг нэгэндээ үйлчилж чаддаг. Залуу болон ахмад ах эгч нарын хооронд нөхөрлөлийн гүүр баригдаж, Бурханы хайрын улмаас та нар бие биеэ илүү сайн ойлгож чаддаг. Залуу ах эгч нар нь ахмад ах эгч нараа үл тоомсорлодоггүй, харин ахмад ах эгч нар нь өөрсдийгөө зөвтгөдөггүй, энэ харилцаа эв эетэй харилцаа бус уу? Хэрвээ та нар бүгд ийм шийдэмгий бол Бурханы хүсэл танай үед гарцаагүй биелнэ.

Хожим ерөөгдөх, хараагдах эсэхийг чинь та нарын өнөөдрийн хийх үйлдэл, зан авирт үндэслэн шийднэ. Хэрвээ та нар Бурханаар төгс болгуулъя гэвэл яг одоо энэ эринд л хийх ёстой; ирээдүйд өөр боломж олдохгүй. Бурхан одоо та нарыг төгс болгохыг үнэхээр хүсдэг ба энэ нь яриа төдийхөн биш юм. Ирээдүйд та нарт ямар шалгалт ирж, ямар үйл явдал болж, ямар гай зовлон тохиолдохоос үл хамааран Бурхан та нарыг төгс болгохыг хүсдэг; энэ бол лавтай агаад маргахын аргагүй баримт юм. Хаанаас үүнийг харж болох вэ? Эрин үеүдийн туршид Бурханы үг хэзээ ч өнөөдрийнх шиг, ийм их өндөрлөгт хүрч байгаагүй гэдэг баримтаас үүнийг харж болно. Энэ нь хамгийн дээд ертөнцөд нэвтэрсэн бөгөөд өнөөгийн хүн төрөлхтөнд хийсэн Ариун Сүнсний ажил урьд өмнө үзэгдээгүй ажил юм. Өнгөрсөн үеийнхнээс ийм туршлага авсан хүн бараг байхгүй; Есүсийн эрин үед ч өнөөдрийн илчлэл байгаагүй. Та нарт хэлсэн үг, та нарын ойлгосон зүйл, та нарын туршлага бүгд шинэ өндөрлөгт хүрсэн. Шалгалт, гэсгээлтийн дундаас хүмүүс та нар явдаггүй, энэ бол Бурханы ажил урьд өмнө үзэгдээгүй сүр жавхлант байдалд хүрснийг батлахад хангалттай. Хүний хийж чадах зүйл энэ биш, хүний бат зогсдог зүйл ч бас биш, харин Бурханы Өөрийнх нь ажил юм. Иймээс Бурханы ажлын маш олон бодит байдлаас Бурхан хүнийг төгс болгохыг хүсдэг, бас Тэр та нарыг гарцаагүй бүрэн төгс болгож чадна гэдгийг харж болно. Хэрвээ та нарт ийм мэдлэг ухаан байгаа бөгөөд энэхүү шинэ нээлтийг хийсэн бол Есүсийн хоёр дахь ирэлтийг хүлээхийн оронд та нарыг өнөөгийн эрин үед бүрэн төгс болгохыг Бурханд зөвшөөрнө. Тиймээс та нар бүгд чадах бүхнээ хийж, бүх хүчээ дайчлах ёстой, ингэж чадвал Бурхан та нарыг төгс болгож магадгүй юм.

Одоо сөрөг зүйлсэд анхаарал хандуулах ёсгүй. Эхлээд чи сөрөг сэтгэгдэл төрүүлдэг зүйл бүрийг хойш нь тавьж, умарт. Чи аливаа хэрэг явдалд хандахдаа эрж судалж, тэмтчин урагшилдаг, Бурханд захирагддаг зүрх сэтгэлээр хандах ёстой. Та нар сул талаа олж илрүүлэх бүрдээ эрхшээлд нь оролгүй, үүнийгээ үл харгалзан хийх ёстой үүргээ биелүүлдэг бол нааштай алхам хийсэн байна. Жишээлбэл: Ахмад ах эгч нарт чинь шашны үзэл байдаг хэдий ч чи залбирч, захирагдаж, Бурханы үгийг идэж ууж, магтан дуу дуулж чаддаг… Нэг үгээр хэлбэл, өөрийн хийж чадах ямар ч зүйлийг, өөрийн гүйцэтгэж чадах ямар ч үүргийг биелүүлэхдээ бүхий л хүчээ дайчлан өөрийгөө зориулах хэрэгтэй. Идэвхгүйгээр

бүү хүлээ. Үүргээ гүйцэтгэхдээ Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаг байх нь эхний алхам юм. Дараа нь үнэнийг ойлгож, Бурханы үгийн бодит байдалд орж чадах үедээ чи Бурханаар төгс болгуулсан байх болно.

БУРХАН ХҮНИЙГ АШИГЛАХ ТАЛААР

Ариун Сүнс тусгай чиглэл, удирдамж өгсөн хүмүүсээс өөр хэн ч бие даан амьдрах чадваргүй, учир нь тэдэнд Бурханаар ашиглагдаж буй хүмүүсийн үйлчлэл болон хариулга шаардлагатай байдаг. Тиймээс эрин үе болгонд Бурхан, Өөрийнх нь ажлын төлөө чуулганууды хариулахаар завгүй яаравчлан ажилладаг өөр өөр хүмүүсийг өргөн босгодог. Өөрөөр хэлбэл, Бурханы ажил нь Түүний нааштайгаар онцлон үзэж, зөвшөөрдөг хүмүүсээр дамжин хийгдэх ёстой; Ариун Сүнс ажиллахын тулд тэдний дотор байгаа ашиглаж болох хэсгийг нь ашиглах ёстой байдаг ба Ариун Сүнсээр төгс болгуулснаар дамжуулан тэд Бурхан ашиглахад тохиромжтой болдог. Хүний ойлгох чадвар хэтэрхий дутмаг учраас Бурханы ашигладаг хүмүүс тэднийг хариулах ёстой; Бурхан Мосег ашиглахад ч ийм байсан, Тэр түүнээс тухайн үед ашиглахад тохиромжтой олон зүйлийг олсон бөгөөд тухайн үе шатан дахь Бурханы ажлыг хийхдээ үүнийг нь ашигласан юм. Энэ үе шатанд Бурхан, Ариун Сүнс ажиллахад хэрэглэж болох хэсгээр нь дамжуулан хүнийг ашигладаг бөгөөд Ариун Сүнс хүнийг чиглүүлэхийн зэрэгцээ ашиглаж болохгүй, үлдсэн хэсгийг нь ч төгс болгож байдаг.

Бурханы ашигладаг хүний гүйцэтгэдэг ажил нь Христ юм уу Ариун Сүнсний ажилтай хамтран ажиллахын төлөө байдаг. Энэ хүнийг Бурхан хүмүүсийн дундаас өргөдөг бөгөөд тэрээр Бурханы сонгосон бүх хүнийг удирдан хөтлөхийн төлөө, бас хүний хамтын ажиллагааны ажлыг гүйцэтгэхийн тулд Бурханаар өргөгддөг билээ. Хүний хамтын ажиллагааны ажлыг хийх чадвартай ийм хүн байснаар хүнд тавих Бурханы шаардлага болон хүмүүсийн дунд Ариун Сүнсний хийх ёстой ажлын дийлэнх нь түүгээр дамжин биелж болно. Үүнийг өөрөөр хэлэх юм бол: Энэ хүнийг ашиглах Бурханы зорилго нь Бурханыг дагадаг бүх хүнд Бурханы хүслийг илүү сайн ойлгуулж, тэднийг Бурханы илүү олон шаардлагад хүрч чаддаг болгохын төлөө байдаг. Хүмүүс Бурханы үгийг, эсвэл Бурханы хүслийг шууд ойлгох чадваргүй учраас тийм ажил гүйцэтгэхэд ашиглагдах хэн нэгнийг Бурхан өргөсөн. Бурханы ашигладаг энэ хүнийг хүмүүсийг залж чиглүүлдэг Бурханы зууч, Бурхан хүн хоёрыг хэл нэвтрэлцүүлдэг “орчуулагч” хэмээн тодорхойлж бас болно. Тиймээс ийм хүн бол Бурханы гэрт ажилладаг хүмүүс, эсвэл Түүний элчүүдийн хэнтэй ч адилгүй юм. Тэдний адилаар, түүнийг Бурханд үйлчилдэг нэгэн гэж хэлж болох ч түүний ажлын мөн чанар болон Бурханаар ашиглагдаж буйн цаад шалтгаан нь бусад ажилчид, элчүүдээс асар их ялгаатай байдаг. Түүний ажлын мөн чанар болон түүнийг ашиглах цаад шалтгааны тухайд гэвэл, Бурханаар ашиглагддаг хүнийг Бурхан

өргөдөг, мөн Бурхан түүнийг Бурханы ажлын төлөө бэлдэж, тэрээр Бурханы Өөрийн ажилд хамтран ажилладаг. Хэн ч, хэзээ ч түүний ажлыг орлож чадахгүй—энэ нь бурханлаг ажлаас салшгүй хүний хамтын ажиллагаа юм. Харин бусад ажилчид юм уу элчүүдийн гүйцэтгэдэг ажил нь зүгээр л цаг үе болгонд чуулгануудын зохицуулалтын олон талыг хэрэгжүүлж, дамжуулах явдал, эсвэл чуулганы амьдралыг хэвээр хадгалахын тулд амиар хангах зарим нэг энгийн ажил байдаг. Энэ ажилчид болон элчүүдийг Бурхан томилдоггүй, тэднийг Ариун Сүнсний ашигладаг хүмүүс гэж нэрлэж бүр ч болохгүй. Тэднийг чуулгануудын дотроос сонгодог бөгөөд хэсэг хугацаанд сургаж, боловсруулсны дараа тохирох хүмүүсийг нь үлдээдэг, харин тохирохгүй хүмүүсийг ирсэн газар луу нь буцаан илгээдэг. Энэ хүмүүсийг чуулгануудын дотроос сонгодог учраас зарим нь удирдагч болсныхоо дараа жинхэнэ нүүр царайгаа харуулж, зарим нь олон муу зүйл ч хийж, эцэстээ таягдан хаягддаг. Нөгөө талаар, Бурханы ашигладаг хүн бол Бурханаар бэлтгэгдсэн, тодорхой хэв чанартай, хүн чанартай хүн юм. Түүнийг Ариун Сүнс урьдчилан бэлтгэж, төгс болгосон байдаг бөгөөд Ариун Сүнс бүрэн удирддаг, ялангуяа түүний ажлын тухайд гэвэл Ариун Сүнс түүнийг чиглүүлж, захирч байдаг—үүний үр дүнд Бурханы сонгосон хүмүүсийг залж чиглүүлэх замд ямар ч гажуудал байдаггүй, учир нь Бурхан Өөрийн ажлыг гарцаагүй хариуцдаг бөгөөд Өөрийн ажлыг цаг ямагт хийж байдаг билээ.

ТА НАР ҮНЭНИЙГ ОЙЛГОМОГЦОО ХЭРЭГЖҮҮЛЭХ ЁСТОЙ

Бурханы ажил болон үг нь та нарын зан чанарт өөрчлөлт авчрахын төлөө юм; Түүний зорилго нь Өөрийн ажил болон үгийг та нарт ойлгуулж, мэдүүлэх төдий биш. Ингэх нь хангалтгүй юм. Бурханы үгийн ихэнх нь хүний хэлээр бичигдсэн бөгөөд Тэр тун ойлгомжтой ярьдаг болохоор ухаарч ойлгох чадвартай хүн чамд үүнийг ойлгох нь хэцүү байх учиргүй. Жишээ нь, Бурхан чамайг юуг ойлгож, хэрэгжүүлээсэй гэж хүсэж байгааг чи олж мэдэх бүрэн чадамжтай; энэ бол ухаарч ойлгох чадвартай хэвийн хүний хийж чадах ёстой зүйл. Ялангуяа одоогийн үе шатанд Бурханы хэлж байгаа үгс маш тодорхой, ил тод бөгөөд хүмүүсийн бодож үзээгүй олон зүйлээс гадна хүний бүх төрлийн байдлыг Бурхан онцолж байдаг. Түүний үг бүхнийг хамардаг бөгөөд тэргэл сарны гэрэл шиг тод байдаг. Тиймээс хүмүүс одоо олон асуудлыг ойлгодог боловч тэдэнд одоо ч дутагдсаар байгаа зүйл бол Түүний үгийг хэрэгжүүлэх явдал юм. Хүмүүс зүгээр л бэлэн өгсөн зүйлийг ойлгож авах гэж хүлээх бус, үнэний бүх талыг нарийвчлан туулж, илүү нарийн судалж, эрж хайх ёстой; эс бөгөөс тэд шимэгчээс нэг их дээрдэхгүй. Тэд Бурханы үгийг мэддэг боловч хэрэгжүүлдэггүй. Ийм хүн үнэнийг хайрладаггүй бөгөөд эцсийн дүнд таягдан хаягдах болно. 90-ээд оны Петр шиг байна гэдэг нь та нарын хүн нэг

бүр Бурханы үгийг хэрэгжүүлж, өөрсдийн туршлагад жинхэнэ оролттой байж, Бурхантай хамтран ажиллахдаа улам илүү, бүр их гэгээрлийг олж авах ёстой бөгөөд энэ нь аминд чинь байнга нэмэгдэх дэмжлэг болно гэсэн үг юм. Бурханы маш олон үгийг уншсан ч та нар бичвэрийн утгыг нь л ойлгодог бөгөөд бодит туршлагаар олж авсан Бурханы үгийн талаарх шууд мэдлэг чинь хангалтгүй байвал Бурханы үгийг чи мэдэж авахгүй. Чиний хувьд, Бурханы үг амь биш, ердөө л амьгүй үсэг юм. Хэрэв чи зөвхөн амьгүй үсэг дагаж амьдарвал Бурханы үгийн мөн чанарыг ухаарч чадахгүй, Түүний хүслийг ч ойлгохгүй. Бодит туршлагаараа Бурханы үгийг туулсан үед л Түүний үгийн сүнслэг утга чамд илчлэгдэх бөгөөд зөвхөн туршлагаараа чи олон үнэний сүнслэг утгыг ухаарч, Бурханы үгийн нууцыг тайлж чадна. Хэрэв чи үүнийг хэрэгжүүлдэггүй бол Түүний үг хэдий тодорхой байсан ч чиний ухаарч авсан ганц зүйл нь хоосон үсэг, сургаал байх бөгөөд энэ нь чиний хувьд шашны дүрэм болсон байдаг. Энэ нь фарисайчуудын хийсэн зүйл бус уу? Хэрэв та нар Бурханы үгийг хэрэгжүүлж, туулах аваас энэ нь та нарын хувьд бодит зүйл болно; хэрэв та нар үүнийг хэрэгжүүлэхээр эрж хайхгүй бол Бурханы үг та нарын хувьд гуравдагч тэнгэрийн домгоос бараг ялгаагүй болно. Үнэндээ Бурханд итгэх үйл явц бол та нар Түүний үгийг туулж, Түүгээр авхуулах үйл явц бөгөөд үүнийг илүү тодорхой байдлаар хэлбэл Бурханд итгэх гэдэг нь Түүний үгийн талаар мэдлэг болон ойлголттой байж, Түүний үгийг туулж, амьдран харуулах явдал; энэ бол Бурханд итгэх итгэлийн чинь цаадах бодит байдал юм. Бурханд итгэхдээ Бурханы үгийг хэрэгжүүлж, үнэн-бодит байдалд орохоор эрж хайлгүйгээр зөвхөн мөнх амь горьддог бол та нар мунхаг байна. Энэ нь найрт очоод өөрөө огт амсаж үзэлгүйгээр хоолыг нь л харж, амттай зүйлсийг нь цээжилж авахтай адил, тэндхийн юуг ч идэж, уухгүй байгаатай адил юм. Ийм хүн тэнэг биш гэж үү?

Хүн эзэмших ёстой үнэнээ Бурханы үгээс олдог бөгөөд энэ бол хүн төрөлхтөнд хамгийн ашиг тустай, хэрэгтэй үнэн юм. Энэ бол та нарын бие махбодод хэрэгтэй ханд, тэжээл бөгөөд хэвийн хүн чанараа сэргээхэд нь хүнд тусалдаг зүйл, хүний зэвсэглэх ёстой үнэн юм. Бурханы үгийг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, та нарын амь төдий чинээ хурдан цэцэглэж, үнэн төдий чинээ тодорхой болно. Биеийн хэмжээ чинь өсөх тусам та бүхэн сүнслэг ертөнцийн зүйлсийг илүү тодорхой харж, Сатаныг ялан дийлэх илүү их тэнхээтэй болно. Бурханы үгийг хэрэгжүүлснээр ойлгохгүй байсан олон үнэн чинь та нарт тодорхой болно. Ихэнх хүмүүс Бурханы үгийн бичвэрийг ойлгох төдийдөө сэтгэл ханадаг бөгөөд туршлагаа гүнзгийрүүлэн хэрэгжүүлэхийн оронд, өөрсдийгөө хоосон сургаалаар зэвсэглэхэд анхаардаг; гэвч энэ нь фарисайчуудын зам бус уу? Ийм байхад “Бурханы үг бол амь юм” гэсэн хэллэг тэдний хувьд яаж жинхэнэ байж чадах юм бэ? Бурханы үгийг унших төдийхнөөр бус гагцхүү түүнийг хэрэгжүүлсэн үед л хүний амь өснө. Хэрэв Бурханы үгийг ойлгох нь амь болон биеийн хэмжээтэй болоход хэрэгтэй бүхэн юм гэж чи итгэж байвал ойлголт чинь ташаа байна. Үнэнийг хэрэгжүүлсэн цагт Бурханы үгийг үнэхээр ойлгох бөгөөд “үнэнийг хэрэгжүүлснээр л үүнийг ойлгож чадна” гэдгийг чи

ойлгож авах ёстой. Өнөөдөр Бурханы үгийг уншсаныхаа дараа чи Бурханы үгийг мэдлээ гэж л хэлж болно, харин ойлгочихлоо гэж хэлж болохгүй. Үнэнийг хэрэгжүүлэх цорын ганц зам бол эхлээд үүнийг ойлгох явдал гэж зарим хүн хэлдэг ч энэ нь ердөө зарим талаараа зөв бөгөөд бүхэлдээ үнэн зөв биш гэдэг нь лавтай юм. Үнэний талаар мэдлэгтэй болохоосоо өмнө чи тэр үнэнийг туулаагүй байдаг. Номлолоос сонсдог зүйлээ ойлгодог гэж чамд санагдах нь үнэндээ ойлгож байгаа хэрэг биш. Зүгээр л үнэний үг үсгийг эзэмшсэн төдий бөгөөд энэ нь үнэний жинхэнэ утгыг ойлгохтой адилгүй. Үнэний талаар зөвхөн өнгөц мэдлэгтэй байгаа чинь үнэндээ ойлгодог, эсвэл энэ талаар мэдлэгтэй гэсэн үг биш; үнэний жинхэнэ утга нь үнэнийг туулснаар гарч ирдэг. Тиймээс зөвхөн үнэнийг туулах үедээ чи үүнийг ойлгож чадна, тэр цагт л чи далд хэсгүүдийг нь ухаарч чадна. Туршлагаа гүнзгийрүүлэх нь үнэний далд утгыг ухаарах, мөн чанарыг нь ойлгох цорын ганц зам юм. Тиймээс үнэнтэй байхад чи хаа ч хүрж чадах боловч дотор чинь үнэн байхгүй бол шашны хүмүүс байтугай, гэр бүлийн гишүүдээ ч итгүүлэх гэж оролдох талаар бодох хэрэггүй. Үнэн байхгүй бол чи будрах цасан ширхэгтэй л адил байх болно, харин үнэнтэй бол аз жаргалтай, эрх чөлөөтэй байж чадах бөгөөд хэн ч чам руу дайрч чадахгүй. Онол хэр баттай байх нь хамаагүй, үнэнийг даван гарч чадахгүй. Үнэнтэй байхад дэлхийг ч хөдөлгөж, уулс хийгээд тэнгис далайг ч нүүлгэж болно, харин үнэн дутмаг бол хотын бат бэх хана хэрэм өтөнд идэгдэж юу ч үгүй болоход хүрнэ. Энэ бол илэрхий бодит байдал.

Одоогийн үе шатанд эхлээд үнэнийг мэдээд, дараа нь үүнийгээ хэрэгжүүлэх, мөн цаашид үнэний жинхэнэ утгаар өөрийгөө зэвсэглэх нь нэн чухал юм. Та нар үүнд хүрэхээр эрж хайх ёстой. Бусдыг үгээрээ дагуулах төдий бус, харин хэрэгжүүлэлтээрээ дагуулах ёстой, ингэж байж л чи утга учиртай зүйлийг олж чадна. Чамд юу тохиолдох нь хамаагүй, ямар хүнтэй учрах нь хамаагүй чамд үнэн байгаа цагт бат зогсож чадна. Бурханы үг хүнд үхэл бус, амь авчирдаг зүйл. Хэрэв Бурханы үгийг уншсаныхаа дараа чи амь орж сэргэхгүй, харин үхмэл хэвээр байвал чиний ямар нэгэн зүйл буруу байна. Хэрэв чи хэсэг хугацааны дараа Бурханы үгийг нэлээд уншиж, олон бодитой номлол сонссон ч үхмэл байдалтай хэвээр байгаа бол чи үнэнийг нандигнадаг нэгэн биш, үнэнийг эрэлхийлдэг хүн ч биш гэдгийг энэ нь нотолдог. Хэрэв та нар Бурханыг олж авахаар үнэхээр эрж хайсан бол хоосон сургаалаар өөрсдийгөө зэвсэглэж, сүртэй сургаал ашиглаж бусдад заахад анхаарахын оронд Бурханы үгийг туулж, үнэнийг хэрэгжүүлэхэд төвлөрөх байсан. Энэ чинь одоо та нарын орохоор эрж хайх ёстой зүйл биш гэж үү?

Өөрийн ажлыг хүнд хийхэд зарцуулах цаг Бурханд хязгаарлагдмал байдаг учраас чи Түүнтэй хамтран ажиллахгүй бол ямар үр дүн гарах билээ? Түүний үгийг ойлгомогцоо хэрэгжүүлэхийг Бурхан та нараас яагаад үргэлж хүсдэг вэ? Учир нь Бурхан Өөрийн үгийг та нарт илчилсэн бөгөөд та нарын дараагийн алхам бол тэдгээрийг хэрэгжүүлэх явдал юм. Та нар эдгээр үгийг хэрэгжүүлэхэд Бурхан гэгээрэл болон удирдамжийн ажлаа гүйцэтгэнэ. Үүнийг ингэж хийдэг. Бурханы үг

нь амиа цэцэглүүлэх боломжийг хүнд олгодог бөгөөд хүнийг гажуудах эсвэл идэвхгүй болоход хүргэж болзошгүй элемент агуулдаггүй. Бурханы үгийг уншиж, хэрэгжүүлсэн боловч Ариун Сүнсний ямар ч ажлыг хүлээн аваагүй л байгаа гэж чи хэлдэг. Чиний үг зөвхөн хүүхэд л хуурч чадна. Чиний санаа зорилго зөв эсэхийг бусад хүн мэдэхгүй байж магадгүй ч Бурхан мэдэхгүй байх боломжтой гэж чи бодож байна уу? Бусад хүн Бурханы үгийг хэрэгжүүлээд, Ариун Сүнсний гэгээрлийг хүлээж аваад байхад чи яагаад Түүний үгийг хэрэгжүүлдэг атлаа Ариун Сүнсний гэгээрлийг хүлээн авдаггүй юм бэ? Бурхан сэтгэл хөдлөлтэй юу? Хэрэв санаа зорилго чинь үнэхээр зөв бөгөөд чи хамтран ажилладаг бол Бурханы Сүнс чамтай хамт байх болно. Зарим хүн үргэлж өөрсдийнхөө тугийг хатгахыг хүсдэг ч Бурхан яагаад тэднийг өргөж, чуулганыг удирдуулдаггүй вэ? Зарим хүн зүгээр л чиг үүргээ биелүүлж, үүрэг даалгавраа биелүүлдэг ба нэг л мэдэхэд Бурханы сайшаалыг хүртдэг. Яагаад ингэдэг юм бэ? Бурхан хүний зүрх сэтгэлийн гүнийг шалгадаг бөгөөд үнэнийг эрэлхийлдэг хүмүүс зөв санаа зорилготой байх ёстой. Санаа зорилго нь зөв биш хүмүүс бат зогсож чадахгүй. Та нарын зорилгын гол цөм нь Бурханы үг дотор чинь нөлөө үзүүлж эхлүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, Бурханы үгийг хэрэгжүүлэхдээ үүний талаар жинхэнэ ойлголтой байх явдал юм. Магадгүй Бурханы үгийг ухаарч ойлгох та нарын чадвар ядмаг байж болох ч Бурханы үгийг хэрэгжүүлэх үед Тэр энэ дутагдлыг чинь нөхөж чадна, иймээс та нар зөвхөн олон үнэнийг мэдээд зогсохгүй, бас тэдгээрийг хэрэгжүүлэх ёстой. Энэ бол үл ойшоож болохгүй хамгийн гол анхаарах зүйл билээ. Есүс гучин гурван жил хагасын хугацаандаа ихээхэн доромжлол туулж, их зовсон. Тэрээр үнэнийг хэрэгжүүлж, бүх зүйл дээр Бурханы хүслийг гүйцэтгэж, гагцхүү Бурханы хүслийг анхаарсан учраас л асар их зовсон билээ. Тэр зүгээр л үнэнийг мэдээд, хэрэгжүүлдэггүй байсан бол ийм зовлон шаналлыг туулахгүй байх байсан. Хэрэв Есүс иудейчүүдийн сургаалыг дагаж, фарисайчуудыг дагасан бол зовохгүй байх байсан. Бурханы ажлын үр нөлөө хүний хамтын ажиллагаанаас шалтгаалдаг болохыг чи Есүсийн үйл хэргээс мэдэж авч болно, энэ бол та нарын таньж мэдэх ёстой зүйл. Хэрэв Есүс үнэнийг хэрэгжүүлээгүй бол Тэр загалмайд цовдлогдож зовох байсан уу? Хэрэв Тэр Бурханы хүсэлд нийцүүлэн үйлдээгүй байсан бол тийм зовлонт залбирал хийх байсан уу? Тиймээс та нар үнэнийг хэрэгжүүлэхийн төлөө зовох ёстой; энэ бол хүний туулах ёстой зовлон юм.

АВРАЛД ХҮРДЭГ ХҮН БОЛ ҮНЭНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ХҮСДЭГ ХҮН ЮМ

Зүй зохистой чуулганы амьдралтай байх шаардлагатайг номлолуудад байнга дурддаг. Тэгвэл яагаад чуулганы амьдрал одоо ч дээрдээгүй, урьдын хэвээр байсаар байна вэ? Цоо шинэ, өөр амьдралын хэв маяг яагаад байхгүй байна вэ?

Ерээд оны хүн аль өнгөрсөн үеийн эзэн хаан шиг амьдрах нь зохистой байж болох уу? Хүмүүсийн одоо идэж, уудаг амттаныг өмнөх эрин үеүдэд ховорхон амсаж байсан байж болох боловч чуулганы амьдралд томоохон эргэлт гарсангүй. Энэ нь хуучин дарсыг шинэ лонхонд хийж байгаагаас ялгаа алга байсан. Тэгвэл Бурхан ийм их үг хэлэхийн хэрэг юу байна вэ? Ихэнх газрын чуулганууд ер өөрчлөгдсөнгүй. Үүнийг Би нүдээрээ үзсэн бөгөөд энэ нь Миний зүрх сэтгэлд тодорхой байна; хэдий Би чуулганы амьдралыг Өөрөө туулаагүй ч, чуулганы цугларалтын нөхцөл байдлыг гарын арван хуруу шигээ мэддэг. Тэд тийм ч их ахиц гаргаагүй. Өмнө хэлсэнчлэн, энэ нь хуучин дарсыг шинэ лонхонд хийж байгаатай яг адилхан. Юу ч өөрчлөгдсөнгүй! Хэн нэгэн өөрсдийг нь хариулж байхад тэд гал шиг асдаг боловч өөрсдийг нь дэмжих хэн ч байхгүй байх үед хэсэг мөс шиг байдаг. Бодитой зүйлсийн талаар ярьж чадах хүн олон биш бөгөөд удирдлагыг гартаа авч чадах хүн тун ховорхон. Номлолууд хэдийгээр сүрлэг байдаг ч оролтод хүрсэн хүн бараг үгүй. Цөөн хүн Бурханы үгийг нандигнадаг. Тэд Бурханы үгийг хүлээн авах үедээ нулимс асгаруулж, хойш тавих үедээ баяр хөөртэй болж, түүнээс холдохоороо үлбийж, өнгө зүсгүй болдог. Шулуухан хэлэхэд, та нар Бурханы үгийг огт нандигнадаггүй бөгөөд өнөөдөр Түүний амнаас гардаг үгийг эрдэнэ гэж хэзээ ч хардаггүй. Түүний үгийг уншихдаа та нар түгшиж, цээжлэхэд хэцүү санагддаг ба Бурханы үгийг хэрэгжүүлэх тухайд гэвэл худгийн насосын бариулыг адууны хялгасаар эргүүлэхээр оролдож байгаатай адилхан—хэчнээн ч шаргуу хичээлээ гэсэн та нар хангалттай эрч хүч гаргаж ердөө чаддаггүй. Бурханы үгийг уншихдаа үргэлж сэргэдэг атлаа хэрэгжүүлэх үедээ мартаж байдаг. Үнэндээ эдгээр үгийг ингэж уйгагүй хэлж, ийм тэвчээртэй давтах хэрэггүй юм; хүмүүс Бурханы үгийг хэрэгжүүлэлгүйгээр зүгээр л сонсдог байдал нь Бурханы ажилд саад болсон. Би үүнийг сөхөхгүй байж чадахгүй нь, энэ талаар ярихгүй байж чадахгүй нь. Би ингэж хийхээс аргагүй; бусдын сул талыг ил болгох дуртайдаа ингэж байгаа юм биш. Хэрэгжүүлэлт чинь бараг л хангалттай бөгөөд илчлэл оргилдоо хүрэхэд та нарын оролт мөн оргилдоо хүрсэн гэж та нар боддог гэж үү? Энэ тийм энгийн гэж үү? Өөрсдийн чинь туршлага үндсэндээ бий болдог суурийг та нар хэзээ ч шинжилдэггүй! Энэ мөчид, та нарын цугларалтыг чуулганы зохистой амьдрал гэж нэрлэж огт болохгүй, мөн зохистой сүнслэг амьдрал бас огт биш. Энэ бол ердөө л чалчиж, дуулах дуртай хэдэн хүний цугларалт юм. Хатуухан хэлэхэд, үүнд бодит байдал нэг их алга. Улам тодруулж хэлбэл, хэрвээ чи үнэнийг хэрэгжүүлдэггүй бол бодит байдал хаана байна вэ? Өөрийгөө бодит байдалтай гэж хэлдэг чинь сайрхал бус уу? Үргэлж ажил гүйцэтгэдэг хүмүүс биеэ тоосон, ихэрхүү байдаг байхад үргэлж дуулгавартай дагадаг хүмүүс дуугүй байж, толгой гудайж, сургалтын ямар ч боломжгүй байдаг. Ажил хийдэг хүмүүс ярихаас өөрийг хийлгүй, сүржин яриагаа л үргэлжлүүлсээр байдаг бөгөөд дагалдагчид зөвхөн сонсдог, ярих ямар ч өөрчлөлт байдаггүй, энэ бүгд нь ердөө л өнгөрсөн үеийн арга зам юм! Өнөөдөр, захирагдаж чадаж байгаа, мөн саад болох буюу дур зоргоороо авирлаж зүрхлэхгүй байгаа чинь Бурханы

захиргааны зарлиг ирснээс болж байгаа юм; энэ нь туршлагаар дамжуулан чиний туулсан өөрчлөлт биш. Бурханы захиргааны зарлигийг зөрчдөг зарим зүйлийг чи өнөөдөр хийж зүрхлэхээ больсон нь Бурханы үгийн ажил илэрхий нөлөөтэй байсан бөгөөд хүмүүсийг байлдан дагуулсан учраас тэр юм. Би хэн нэгнээс асууя: Өнөөдрийн ололт амжилтын хэчнээнийг нь чи өөрийн шаргуу ажлын хөлс хүчээр олсон бэ? Үүнээс хэчнээнийг нь Бурхан чамд шууд хэлж өгсөн бэ? Чи юу гэж хариулах вэ? Чи мэгдэн сандарч, хэлэх үггүй болох уу? Бусад нь чамайг тэжээлээр хангах гэж өөрсдийн олон бодитой туршлагын талаар илэн далангүй ярьж чадаж байхад чи зүгээр л бусдын хийсэн хоолыг таашаан суудаг нь ямар учиртай юм бэ? Чамд ичгүүртэй санагдахгүй байна уу? Та нар баримт-олох шинжилгээ явуулж, харьцангуй сайн хүмүүсийг шинжилж болох юм: Чи хэр их үнэнийг ойлгодог вэ? Үндсэндээ хэр ихийг хэрэгжүүлдэг вэ? Чи хэнийг нь илүү хайрладаг вэ, Бурханыг уу, эсвэл өөрийгөө юу? Чи өгөх нь их байдаг уу, эсвэл авах нь их байдаг уу? Санаа зорилго чинь буруу байх үед чи хэчнээн удаа хуучин би-гээ хаяж, Бурханы хүслийг хангасан бэ? Энэ хэдхэн асуулт л олон хүнийг тэвдүүлнэ. Ихэнх хүмүүсийн хувьд өөрсдийнх нь санаа зорилго буруу байгааг ухаарсан ч гэсэн бурууг санаатайгаар хийдэг бөгөөд өөрсдийн махан биеийг яагаад ч хаядаггүй. Ихэнх хүн өөрсдийн доторх нүглийг хяналтаасаа гаргаж, үйлдэл бүрээ нүглээр удирдуулдаг. Тэд өөрсдийн нүглийг ялан дийлж чаддаггүй бөгөөд нүгэлд амьдарсаар байдаг. Одоогийн энэ шатанд ирчхээд, хэчнээн олон ёрын муу үйл хийснээ мэддэггүй хэн байна вэ? Хэрвээ чи мэдэхгүй гэж хэлбэл, чи жишимгүй худлаа ярьж байна. Шулуухан хэлэхэд, энэ бүгд нь хуучин би-гээ хаяхыг хүсэхгүй байгаа хэрэг юм. Үнэ цэнгүй өчнөөн олон гэмшсэн “үгийг зүрх сэтгэлээсээ” хэллээ гээд ямар хэрэгтэй юм бэ? Амиа өсгөхөд чинь энэ тусалдаг уу? Өөрийгөө мэдэх нь бүтэн цагийн ажил юм гэж хэлж болно. Хүмүүсийн дуулгавартай байдал болон Бурханы үгийг хэрэгжүүлдгээр нь дамжуулан Би тэднийг төгс болгодог. Хэрвээ чи хувцас өмсдөг шигээ ухаалаг, гоё ганган харагдахын тулд л Бурханы үгийг өмсдөг бол өөрийгөө болон бусдыг хуурч байгаа бус уу? Хэрвээ чи зөвхөн яриад хэзээ ч хэрэгжүүлдэггүй бол юунд хүрэх юм бэ?

Олон хүн хэрэгжүүлэлтийн тухай бага сага ярьж, өөрсдийн хувийн сэтгэгдлийн тухай ярьж чаддаг боловч үүний дийлэнх нь бусдын үгээс олж авсан гэрэлтүүлэлт байдаг. Энэ нь тэдний өөрсдийнх нь хувийн хэрэгжүүлэлтийн юуг ч агуулдаггүй, туршлагаасаа харсан зүйлийг нь ч агуулдаггүй. Энэ асуудлыг Би өмнө нь задлан шинжилсэн; Намайг юу ч мэдэхгүй гэж бүү бод. Чи цаасан бар төдий мөртөө Сатаныг ялж, ялгуусан гэрчлэл хийж, Бурханы дүр төрхийг амьдран харуулах тухай ярих юм гэж үү? Энэ бүгд утгагүй зүйл! Бурханы өнөөдөр айлдсан бүх үг чамайг бишрүүлэхийн тулд байдаг гэж чи бодож байна уу? Чиний ам, хуучин би-гээ хаях хийгээд үнэнийг хэрэгжүүлэх тухай ярьдаг атал гар чинь өөр үйл үйлдэж, зүрх сэтгэл чинь өөр хуйвалдаан сэддэг—чи ямар гээч хүн бэ? Гар, зүрх сэтгэл хоёр чинь яагаад ав адил биш юм бэ? Өчнөөн олон номлол хоосон үг болжээ; зүрх

шимшрэм биш гэж үү? Хэрвээ чи Бурханы үгийг хэрэгжүүлж чаддаггүй бол Ариун Сүнсний ажилладаг замд хараахан ороогүй, чамд Ариун Сүнсний ажил хараахан байхгүй, мөн Түүний удирдамж чамд хараахан байхгүй гэдгийг энэ нь нотолдог. Хэрвээ чи Бурханы үгийг ойлгож л чаддаг боловч хэрэгжүүлж чаддаггүй гэж хэлбэл чи үнэнийг хайрладаггүй хүн юм. Бурхан ийм хүмүүсийг аврах гэж ирдэггүй. Есүс нүгэлтнүүдийг аварч, ядуусыг аварч, тэр бүх даруу хүнийг аврахын тулд цовдлогдох үедээ асар их зовлон шаналлыг амссан. Түүний цовдлол нүглийн тахил болсон. Хэрвээ чи Бурханы үгийг хэрэгжүүлж чаддаггүй бол аль болох хурдан явах хэрэгтэй; Бурханы гэрт хувалз шиг бүү хоргод. Бурханыг илэрхий эсэргүүцэх зүйлсийг хийхээ болих нь хүртэл олон хүнд хэцүү байдаг. Тэд үхлээ хайж байгаа хэрэг бус уу? Тэд яаж Бурханы хаанчлалд орох тухай ярьж чадаж байна аа? Түүний царайг харах зүрх зориг тэдэнд байх уу? Бурханы өгдөг хоолыг идэж, Түүнд тэрсэлдэг шударга бус юмсыг хийж, Түүний чамд хайрласан ерөөлийг эдлэхийг Бурхан чамд зөвшөөрч байхад хүртэл муу санаатай, дотуур тамиртай байж, хуйвалдаан хийдэг—тэдгээрийг хүлээн авахад гарыг чинь түлж байгаа мэт чамд санагддаггүй гэж үү? Нүүр чинь улайхыг мэдэрдэггүй юм уу? Бурханд тэрсэлсэн зүйл хийж, “дураараа дургих” хуйвалдаан хийчхээд чи айж эмээдэггүй юм уу? Хэрвээ чи юу ч мэдэрдэггүй юм бол яаж ирээдүйн тухай ярьж чадна вэ? Угаасаа чамд аль эртнээс ирээдүй гэж байгаагүй, тиймээс чамд илүү их ямар хүлээлт бас байж болох юм бэ? Хэрвээ чи ямар нэгэн ичгүүргүй зүйл хэлдэг атлаа ямар ч зэмлэл мэдэрдэггүй, зүрх сэтгэл чинь ямар ч мэдрэмжгүй бол чамайг Бурхан аль хэдийнээ хаячихсан гэсэн үг биш гэж үү? Зоргоороо, цадиггүй ярьж, үйлдэх нь чиний уг чанар болжээ; ийм байвал ер нь чи яаж Бурханаар төгс болгуулах юм бэ? Чи дэлхийг тойрон алхаж чадах уу? Хэн чамд үнэмших юм бэ? Чиний жинхэнэ уг чанарыг мэддэг хүмүүс чамаас зай барих болно. Энэ нь Бурханы шийтгэл бус уу? Ерөнхийдөө, зөвхөн яриад, хэрэгжүүлдэггүй бол өсөлт гэж байхгүй. Ярьж байхад чинь Ариун Сүнс чам дээр ажиллаж байж болох ч, хэрвээ чи хэрэгжүүлдэггүй бол Ариун Сүнс ажиллахаа болино. Хэрвээ чи энэ чигээрээ үргэлжлүүлбэл ирээдүйн тухай, эсвэл Бурханы ажилд бүх оршихуйгаа өгөх тухай яриа яаж байж болох юм бэ? Чи бүх оршихуйгаа өргөх тухай ярьж л чаддаг боловч жинхэнэ хайраа Бурханд өгөөгүй. Бурхан чамаас амаараа ярих үнэн сэтгэл л хүлээж авсан. Үнэнийг хэрэгжүүлэх санаа зорилгоо чи Түүнд өгдөггүй. Чиний биеийн жинхэнэ хэмжээ энэ байж болох уу? Хэрвээ чи энэ чигээрээ үргэлжлүүлсээр байвал хэзээ Бурханаар төгс болгуулах бол? Өөрийнхөө харанхуй, бүрхэг ирээдүйн төлөө чи сэтгэл түгшихгүй байна гэж үү? Бурхан чамд найдвар тасарсныг чи мэдрэхгүй байна гэж үү? Бурхан илүү олон, шинэ хүмүүсийг төгс болгохыг хүсэж байгааг чи мэддэггүй гэж үү? Хуучин зүйлс үлдэж чадах уу? Чи Бурханы үгэнд өнөөдөр анхаарал хандуулахгүй байна: Чи маргаашийг хүлээж байна уу?

ШААРДЛАГА ХАНГАДАГ ХОНЬЧНЫ ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ ЗҮЙЛ

Ариун Сүнс дээр нь ажиллах үед хүмүүсийн байх олон байдлын талаар чи ойлголттой байх хэрэгтэй. Ялангуяа Бурханд үйлчлэх үйлчлэлд хамтран ажилладаг хүмүүс эдгээр байдлыг бүр ч нухацтай ухаж ойлгосон байх ёстой. Хэрвээ чи зөвхөн их туршлага, оролтод хүрэх арга замын талаар л ярьдаг бол туршлага чинь хэтэрхий өрөөсгөл болохыг энэ нь харуулдаг. Жинхэнэ байдлаа мэдэхгүйгээр, үнэн-зарчмыг ойлгож авахгүйгээр зан чанарын өөрчлөлтөд хүрэх боломжгүй. Ариун Сүнсний ажлын зарчмыг мэдэж, түүнээс гарах үр дүнг ойлгохгүйгээр ёрын муу сүнсний ажлыг ялган танихад чамд хэцүү байх болно. Чи ёрын муу сүнсний ажил, мөн хүмүүсийн үзлийг илчилж, асуудлын гол цөмийг нь ойлгох ёстой; чи бас хүмүүсийн хэрэгжүүлэлтийн олон гажуудал, Бурханд итгэх итгэлд нь байж болох асуудлуудыг зааж өгөх ёстой бөгөөд ингэснээр хүмүүс тэдгээрийг танин мэдэж болох юм. Ядаж л чи тэдэнд сөрөг юм уу идэвхгүй мэдрэмж төрүүлэх ёсгүй. Гэхдээ чи ихэнх хүмүүсийн хувьд бодитоор оршдог хүндрэл бэрхшээлийг ойлгох ёстой бөгөөд бодлогогүй загнаж, “гахайд дуулахыг заах гэж оролдох” ёсгүй; энэ бол мунхаглал юм. Хүмүүсийн туулдаг олон бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд чи эхлээд Ариун Сүнсний ажлын өрнөл хөгжлийг ухаарч ойлгох ёстой, Ариун Сүнс өөр өөр хүн дээр ажлаа хэрхэн хийдгийг ойлгож, хүмүүст тулгардаг бэрхшээл, тэдний дутагдлыг ойлгож, ямар ч гажуудал, алдаа мадаггүйгээр асуудлын голыг нэвт шувт харж, асуудлын уг сурвалжид хүрэх ёстой. Ийм хүн л зохицон үйлчлэх шаардлага хангадаг.

Гол асуудлыг ойлгож, олон зүйлийг тодорхой харж чадах эсэх нь чиний хувийн туршлагаас хамаардаг. Туршлагажих арга барил чинь мөн бусдыг дагуулдаг арга барил чинь юм. Хэрвээ чи бичиг үсэг, хоосон сургаалуудыг ойлгодог бол бичиг үсэг, хоосон сургаал ойлгоход бусдыг дагуулах болно. Бурханы үгийн бодит байдлыг туулах арга зам чинь бусдыг Бурханы айлдварын бодит байдал руу ороход хөтлөх чиний арга зам юм. Хэрвээ чи Бурханы үгээс олон үнэнийг ойлгож, олон зүйлийн талаар мэдлэг ухаан олж авч үнэхээр чаддаг бол бусдыг ч бас олон үнэнийг ойлгоход хөтөлж чадах бөгөөд чиний дагуулсан хүмүүс үзэгдлийн талаар тодорхой ойлголттой болно. Хэрвээ чи ер бусын мэдрэмжүүдийг ухаж ойлгоход анхаарвал чиний дагуулдаг хүмүүс ч бас мөн адил дуурайна. Хэрвээ чи хэрэгжүүлэлтийг умартаж, хэлэлцүүлгийг чухалчилбал чиний дагуулдаг хүмүүс ч бас огт хэрэгжүүлэхгүйгээр, зан чанарын ямар ч өөрчлөлтгүйгээр зөвхөн хэлэлцэхэд анхаарах ба тэд ямар ч үнэнийг хэрэгжүүлэлгүйгээр гаднаа л урам зоригтой байх болно. Хүмүүс бүгд өөрсдөдөө байгаа зүйлээр бусдыг хангадаг. Хүний төрөл нь ямар зам руу бусдыг чиглүүлэх болон ямар төрлийн хүмүүсийг удирдахыг нь тодорхойлдог. Бурханд ашиглуулахад үнэхээр тохирсон байхын тулд та нарт хүсэл эрмэлзэл байх ёстойгоос гадна, мөн Бурханаас ирэх маш их гэгээрэл,

Бурханы үгийн удирдамж, Бурханы харьцалтын туршлага болон Түүний үгийн цэвэршүүлэлт хэрэгтэй байдаг. Та нар үүнийг үндэс сууриа болгоод, ердийн үед ажиглалт, бодол, эргэцүүлэл, дүгнэлтдээ анхаарал тавьж, зохих ёсоор нь толгойдоо оруулж эсвэл таягдан хаях хэрэгтэй. Эдгээр нь бүгд бодит байдалд орох та нарын зам бөгөөд нэг бүр нь зайлшгүй шаардлагатай. Бурхан ингэж ажилладаг. Хэрвээ чи Бурханы ажилладаг энэ арга барил руу орвол өдөр бүр Бурханаар төгс болгуулах боломжтой байх болно. Хэзээ ч хамаагүй, орчин чинь хатуу ширүүн, эсвэл таатай эсэх, чи туршигдаж байгаа эсвэл соригдож байгаа эсэх, ажиллаж байгаа эсэх, ганцаараа эсвэл хамт олонтой амьдарч байгаа эсэхээс үл хамааран Бурханаар төгс болгуулах боломжийг чи нэгийг ч алдахгүйгээр үргэлж олох болно. Чи тэдгээрийг бүгдийг нь олж мэдэж чадах ба Бурханы үгийг туулах нууцыг чи ийнхүү олсон байх болно.

ТУРШЛАГЫН ТАЛААР

Туршлагынхаа явцад Петр хэдэн зуун шалгалттай тулгарсан. Өнөөдрийн хүмүүс “шалгалт” гэх нэр томьёог мэддэг хэдий ч түүний жинхэнэ утга учир болон нөхцөл байдлын тухайд будилдаг. Бурхан хүмүүсийн шийдэмгий байдлыг батжуулж, итгэлтэй байдлыг нь цэвэршүүлж, хэсэг болгоныг нь төгс болгодог. Үүнд үндсэндээ шалгалтаар дамжуулан хүрдэг бөгөөд энэ нь бас Ариун Сүнсний нууцлаг ажил юм. Бурхан өөрсдийг нь хаячихсан мэт санагддаг болохоор хэрвээ анхааралгүй байвал хүмүүс эдгээр шалгалтыг Сатаны сорилт гэж харах болно. Үнэн хэрэгтээ олон шалгалтыг сорилт гэж үзэж болох ба энэ бол Бурханы ажилладаг зарчим, дүрэм билээ. Хэрвээ хүмүүс үнэхээр Бурханы өмнө амьдардаг бол ийм зүйлсийг Бурханаас ирэх шалгалт гэж харах бөгөөд алдаж явуулахгүй. Бурхан өөрсөдтэй нь хамт байгаа болохоор Сатан яавч ойртохгүй гэж хэн нэгэн хэлж байгаа бол энэ нь яг ч тэр чигээрээ үнэн биш; хэрэв тийм байсан бол Есүс цөлд дөч хоног мацаг барьсныхаа дараа сорилттой тулгарсныг хэрхэн тайлбарлаж болох вэ? Иймээс хүмүүс Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлоо залруулбал олон зүйлийг хавьгүй илүү тодорхой харах тул ойлголт нь буруу, ташаа болохгүй. Хэрвээ хүн Бурханаар төгс болгуулахаар үнэхээр шийдсэн бол зүүн, баруун аль ч тал руу хазайлгүйгээр өөрт тулгардаг хэрэг явдалд олон өөр өнцгөөс хандах ёстой. Хэрвээ чи Бурханы ажлын талаар ямар ч мэдлэггүй бол Бурхантай хэрхэн хамтран ажиллахаа мэдэхгүй. Хэрвээ чи Бурханы ажлын зарчмыг мэддэггүй, Сатан хүн дээр хэрхэн ажилладгийг мэддэггүй бол чамд хэрэгжүүлэлтийн зам байхгүй байх болно. Дан ганц хичээнгүй эрэл хайгуул чамд Бурханы шаардсан үр дүнд хүрэх боломж олгохгүй. Туршлагажих ийм арга барил Лоуренсынхтой адилхан: юмыг огт ялгаж салгахгүй, зөвхөн туршлагад анхаарлаа төвлөрүүлж, Сатаны ажил юу болох, Ариун Сүнсний ажил юу болох, Бурхангүй бол хүн ямар байдалтай байх, Бурхан

ямар төрлийн хүмүүсийг төгс болгохыг хүсдэгийг огт мэдэхгүй байх. Өөр өөр төрлийн хүмүүстэй харьцахдаа ямар зарчим ашиглах ёстой, Бурханы одоогийн хүслийг хэрхэн ухаарах, Бурханы зан чанарыг хэрхэн мэдэх, Бурханы өршөөл, сүр жавхлан, зөвт байдал нь ямар хүмүүс, нөхцөл байдал, эрин үед чиглэдэг гээд эдгээрийн алийг нь ч ялган таних чадвар түүнд байдаггүй. Хэрвээ хүмүүст өөрсдийнх нь туршлагын суурь болсон олон үзэгдэл байхгүй бол амийн талаар ярих ч хэрэггүй, туршлагын тухайд бүр бодолтгүй; тэд бүх зүйлд мунхгаар захирагдаж, тэвчсээр байж чадна. Ийм хүмүүсийг төгс болгоход маш хэцүү. Хэрвээ чамд дээр дурдсан үзэгдлүүдийн аль нь ч байхгүй бол энэ чинь чамайг мулгуу нэгэн, Израильд үргэлж байж байдаг давсан баганатай адил гэдгийг хангалттай нотолж байна гээд хэлчихэд буруудахгүй. Ийм хүмүүс нэмэргүй, ямар ч хэрэггүй! Зарим хүн дандаа л сохроор захирагддаг, тэд үргэлж өөрийн толгой мэдэн, шинэ хэрэг явдлыг зохицуулахдаа дандаа өөрийнхөө хэв маягаар биеэ авч явах юм уу эсвэл дурдаад байх шаардлагагүй шалихгүй асуудлыг зохицуулахдаа “мэргэн ухаан” ашигладаг. Ийм хүмүүс ялган таних чадваргүй, тэд бусдад дээрэлхүүлж байгаатайгаа эвлэрчихсэн юм шиг уг чанартай байдаг бөгөөд үргэлжид хэвээрээ, хэзээ ч өөрчлөгддөггүй. Иймэрхүү хүмүүс бол өчүүхэн төдий ч ялгах таних чадваргүй тэнэгүүд юм. Тэд нөхцөл байдал, эсвэл өөр өөр хүмүүст тохирох арга хэмжээг нь авахаар хэзээ ч оролддоггүй. Ийм хүмүүст туршлага байдаггүй. Муу ёрын сүнсний ажилд эзэмдүүлсэн хүмүүстэй таарах үедээ толгой бөхийж, нүглээ улайдаг бөгөөд эсэргүүцэн босож, тэднийг яллах ч зүрх зориггүй болтлоо өөрсдийн тухай мэдлэгт хүлэгдсэн зарим хүнийг Би харж байсан. Ариун Сүнсний илэрхий ажилтай тулгарах үедээ тэд дуулгавартай дагаж зүрхэлдэггүй. Муу ёрын сүнс ч бас Бурханы гарт байдаг гэж тэд үздэг бөгөөд өндийн босож, тэднийг эсэргүүцэх өчүүхэн ч зориг зүрх тэдэнд байдаггүй. Ийм хүмүүс Бурханд гутамшиг авчирдаг, тэд Бурханы төлөө хүнд ачаа үүрч огт чадахгүй. Ийм тэнэгүүд юмыг огтхон ч ялгаж салгадаггүй. Тиймээс туршлагажих ийм арга барилаас салах ёстой, учир нь Бурханы нүдэнд энэ нь өмгөөлж болшгүй байдаг.

Бурхан үнэндээ л хүмүүст маш их ажил хийдэг, заримдаа тэднийг шалгаж, заримдаа тэднийг хатуужуулах орчныг бий болгож, мөн заримдаа тэднийг залж чиглүүлж, дутагдлыг нь засах үг айлддаг. Заримдаа Ариун Сүнс хүмүүсийг дутагдалтай олон талаа санамсаргүйгээр өөрсдөө нээж илрүүлэг гэсэндээ Бурханы бэлдсэн орчин руу хөтөлдөг. Хүмүүсийн үг, үйлдэл, бусдад болон аливаа зүйлд хандаж буй арга барилаар нь дамжуулан Ариун Сүнс өөрсдөд нь мэдэгдэлгүйгээр, өмнө нь ойлгодоггүй байсан олон зүйлийнх нь талаар хүмүүсийг гэгээрүүлж, олон хүн болон юмсыг илүү тодорхой харах, урьд нь мэддэггүй байсан ихэнх зүйлээ ухаж ойлгох боломж олгодог. Дэлхий ертөнцтэй харилцах үедээ чи хорвоогийн юмсыг аажмаар ялган таньж эхэлдэг бөгөөд насан эцэслэхээсээ өмнө “Хүн байх нь их бэрх юм” гэсэн дүгнэлтэд хүрч магадгүй. Хэрвээ чи Бурханы өмнө туршлагажихад тодорхой хугацаа зарцуулж, Бурханы ажил, Түүний зан чанарыг

ойлгож авсан бол өөрийн мэдэлгүй л ихээхэн мэдлэг ухаан олж авах бөгөөд биеийн хэмжээ чинь аажмаар өснө. Чи олон сүнслэг зүйлийг илүү сайн ойлгох ба ялангуяа Бурханы ажлын талаар илүү тодорхой ойлголттой болно. Чи Бурханы үгс, Бурханы ажил, Бурханы бүх үйлдэл, Бурханы зан чанар болон Бурхан юу болох, Түүнд юу байгааг өөрийн амь хэмээн хүлээн авна. Хэрвээ чи дэлхий ертөнцөөр тэнүүчлэхээс өөр зүйл хийдэггүй бол далавч чинь улам хатуу болж, Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл чинь улам их болно; тийм байхад Бурхан чамайг яаж ашиглах юм бэ? Чиний дотор “миний бодлоор” гэх зүйл хэтэрхий их байгаа учраас Бурхан чамайг ашигладаггүй. Чи хэдий чинээ Бурханы өмнө байна, төдий чинээ их туршлагатай болно. Хэрвээ чи дэлхий дээр адгуус мэт амьдарсаар л, аман дээрээ Бурханд итгэдэг дүр эсгэдэг боловч зүрх сэтгэл чинь өөр хаа нэгтээ байдаг бол, мөн одоо ч хорвоогийн амьдрах ухаанд суралцсаар байгаа бол урьдын бүх хөдөлмөр чинь талаар болох бус уу? Тиймээс хүмүүс Бурханы өмнө байх тусам Бурханаар төгс болгуулах нь төдий чинээ амархан байдаг. Энэ бол Ариун Сүнсний ажлаа хийдэг зам юм. Хэрвээ чи үүнийг ойлгодоггүй бол зөв замд орох боломж чамд байхгүй хийгээд Бурханаар төгс болгуулах талаар ярихын ч хэрэггүй. Чи хэвийн сүнслэг амьдралтай байж чадахгүй, яг л тахир татуу мэт байх ба зөвхөн шаргуу хөдөлмөрлөөд л байхаас биш Бурханы ямар ч ажил чамд байхгүй байх болно. Энэ нь чиний туршлагажилтын алдаа биш гэж үү? Чи Бурханы өмнө байхын тулд заавал залбирах албагүй; заримдаа Бурханыг бодож, эсвэл Түүний ажлыг тунгаан бодсоноор, заримдаа зарим хэрэг явдалтай харьцсанаар, заримдаа үйл явдлаар дамжуулан илчлэгдсэнээр чи Бурханы өмнө очдог. Ихэнх хүмүүс, “Би байнга залбирдаг болохоор Бурханы өмнө байдаггүй гэж үү?” гэж хэлдэг. Олон хүн “Бурханы өмнө” эцэс төгсгөлгүй залбирдаг. Магадгүй тэд аман дээрээ үргэлж залбирч байх боловч үнэндээ бол Бурханы өмнө амьдардаггүй. Ийм хүмүүсийн Бурханы өмнө нөхцөл байдлаа хадгалж чадах цорын ганц арга барил нь энэ юм; Бурхантай цаг ямагт харилцахын тулд зүрх сэтгэлээ ашиглах чадвар тэдэнд огтхон ч байдаггүй, мөн эргэцүүлж, чимээгүйхэн тунгаан бодсоноор туршлагажих юм уу Бурханы ачааг анхаарснаар оюун санаагаа ашиглан зүрх сэтгэлдээ Бурхантай харилцах замаар Бурханы өмнө очиж ч чаддаггүй. Тэд тэнгэр дэх Бурханд зөвхөн аман дээрээ залбирал өргөдөг. Ихэнх хүний зүрх сэтгэл Бурханаас хагацсан байдаг, ойртож ирэх үед нь л Бурхан тэдний зүрх сэтгэлд байдаг юм; ихэнхдээ бол Бурхан тэнд огт байдаггүй. Зүрх сэтгэлд нь Бурхан байдаггүйн илрэл энэ биш гэж үү? Хэрвээ зүрх сэтгэлд нь Бурхан үнэхээр байсан бол дээрэмчид болон адгуусны хийдэг зүйлийг тэд хийж чадах байсан гэж үү? Хэрвээ хүн Бурханыг үнэхээр хүндэлдэг бол үнэн зүрх сэтгэлээр Бурхантай харилцах бөгөөд бодол, санааг нь Бурханы үг үргэлж эзэмдэх болно. Тэд үг болон үйлдлээрээ алдаа гаргахгүй, Бурханыг илт эсэргүүцэх ямар ч зүйл хийхгүй. Итгэгч байх шалгуур ийм байдаг юм.

ШИНЭ ЭРИН ҮЕИЙН ТУШААЛ

Бурханы ажлыг туулахдаа та нар Бурханы үгийг анхааралтай уншиж, өөрсдийгөө үнэнээр зэвсэглэх ёстой. Харин юу хийхийг хүсдэг, хэрхэн хийхийг хүсдэгийн чинь тухайд бол та нарын чин сэтгэлийн залбирал юм уу гуйлт хэрэггүй бөгөөд үнэндээ тэдгээр нь нэмэргүй. Гэвч одоогийн байдлаар та нарт тулгараад байгаа асуудал бол та нар Бурханы ажлыг хэрхэн туулахаа мэддэггүй, мөн дотор чинь ихээхэн идэвхгүй байдал байгаа явдал юм. Олон хоосон сургаал мэддэг хэр нь та нарт бодит байдал нэг их байдаггүй. Энэ нь эндүүрлийн тэмдэг бус уу? Энэ бүлэг хүн та нарт маш их төөрөгдөл байгаа нь илэрхий байна. Өнөөдөр та нар “үйлчлэл үзүүлэгч” гэх мэт шалгалтыг хүртэх чадваргүй, мөн Бурханы үгтэй холбоотой бусад шалгалт, цэвэршүүлэлтийг төсөөлж, хүртэх чадваргүй байдаг. Та нар өөрсдийн хэрэгжүүлэх учиртай олон зүйлийг даган мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдийн биелүүлэх ёстой олон үүргийг баримтлах ёстой байдаг. Үүнийг хүмүүс дагаж мөрдөх ёстой, үүнийг тэд хэрэгжүүлэх ёстой. Ариун Сүнсний хийх ёстой зүйлийг Ариун Сүнсээр хийлгэ; хүн үүнд оролцож болохгүй. Хүн өөрийн хийх ёстой зүйлийг л баримтлах хэрэгтэй ба энэ нь Ариун Сүнстэй ямар ч холбоогүй. Энэ нь хүний хийх учиртай зүйлээс өөр юу ч биш бөгөөд Хуучин Гэрээн дэх хуулийг дагахтай яг л адил тушаал мэт даган мөрдөх ёстой. Хэдийгээр одоо Хуулийн эрин үе биш боловч Хуулийн эрин үед ярьдаг байсантай адил дагаж мөрдөх ёстой олон үг байсаар байгаа. Ариун Сүнс сэтгэл хөдөлгөдөгт найдсанаар л эдгээр үгийг хэрэгжүүлдэггүй, харин эдгээр нь хүний даган мөрдөх ёстой зүйл юм. Жишээлбэл:

Та нар бодитой Бурханы ажлыг шүүх ёсгүй.

Бурханы гэрчилсэн хүнийг эсэргүүцэх ёсгүй.

Бурханы өмнө та нар зөв зохистой авирлах ёстой, замбараагүй байж болохгүй.

Хэл яриа чинь боломжийн байж, үг, үйлдэл чинь Бурханы гэрчилсэн хүний зохицуулалтыг дагах ёстой.

Та нар Бурханы гэрчлэлийг хүндлэх ёстой. Бурханы ажлыг болон Түүний амнаас гарч байгаа үгийг үл тоох ёсгүй.

Та нар Бурханы айлдварын өнгө, зорилгыг дуурайх ёсгүй.

Гаднаа та нар Бурханы гэрчилсэн хүнийг илэрхий эсэргүүцэх ямар нэг зүйл хийж болохгүй, гэх мэтчилэн эдгээрийг хүн бүр даган мөрдөх ёстой.

Эдгээр нь хүн бүрийн даган мөрдөх ёстой зүйл юм. Эрин үе бүрд Бурхан хүний дагаж мөрдөх хуультай төстэй олон дүрэм журмыг тогтоосон. Үүгээр дамжуулан Тэр хүний зан чанарыг хязгаарлан барьж, чин сэтгэлийг нь илрүүлдэг. Жишээ нь, Хуучин Гэрээний эрин үеийн “Эцэг эхээ хүндэл” гэдэг үгийг аваад үз. Эдгээр үг нь өнөөдөр хэрэглэгдэхгүй; тухайн үед, эдгээр үг нь ердөө л хүний зарим гаднах зан чанарыг хазаарлаж, Бурханд итгэх хүний итгэлийн чин сэтгэлийг харуулахын тулд ашиглагдаж байсан, Бурханд итгэж байсан хүмүүсийн тэмдэг байв. Хэдийгээр одоо

Хаанчлалын эрин үе ч гэсэн, хүний даган мөрдөх ёстой олон дүрэм журам байсаар байгаа. Өнгөрсөн үеийн дүрэм журам хэрэглэгддэггүй; өнөөдөр, хүн хэрэгжүүлэхэд илүү тохиромжтой бөгөөд шаардлагатай олон хэрэгжүүлэлт байгаа. Тэдгээрт Ариун Сүнсний ажил хамаарахгүйн дээр хүн хийх ёстой байдаг.

Нигүүлслийн эрин үед Хуулийн эрин үеийн олон хэрэгжүүлэлт хаягдсан, учир нь эдгээр хууль тухайн үеийн ажилд тодорхой үр нөлөөтэй байгаагүй. Тэдгээрийг хаясны дараа тухайн эрин үед тохиромжтой олон хэрэгжүүлэлтийг гаргаж тавьсан нь өнөөдрийн олон дүрэм журам болсон билээ. Өнөөдрийн Бурхан ирэхдээ эдгээр дүрэм журмыг хаяж, цаашид даган мөрдөх хэрэггүй болсны дээр өнөөдрийн ажилд зохимжтой олон хэрэгжүүлэлтийг гаргаж тавьсан. Өнөөдөр, эдгээр хэрэгжүүлэлт нь дүрэм журам биш хэдий ч тодорхой үр дүнд хүрэхийг зорьдог; тэдгээр нь өнөөдөр тохиромжтой—магадгүй маргааш тэдгээр нь дүрэм журам болох болно. Дүгнээд хэлэхэд, чи өнөөдрийн ажилд үр өгөөжтэй дүрмийг даган мөрдөх ёстой. Маргаашийг бүү анхаар: Өнөөдөр хийгдэж байгаа зүйл өнөөдрийн төлөө байдаг. Магадгүй маргааш болоход, чиний хэрэгжүүлэх шаардлагатай илүү дээр хэрэгжүүлэлт гарах болно—гэхдээ түүнд хэтэрхий их анхаарал бүү хандуул. Харин Бурханыг эсэргүүцэхээс зайлсхийхийн тулд өнөөдөр даган мөрдөх ёстой зүйлээ л даган мөрд. Өнөөдөр хүний хувьд, дараах зүйлийг сахин мөрдөхөөс илүү чухал зүйл үгүй:

Нүдний чинь өмнө зогсож байгаа Бурханыг чи аргалахаар оролдох юм уу Түүнээс юу ч нуух ёсгүй.

Урд чинь байгаа Бурханы өмнө чи бузар заваан, биеэ тоосон юм ярьж болохгүй. Бурханы итгэлийг олж авах гэж нүдний чинь өмнө байгаа Бурханыг чихэр шиг үг, сайхан яриагаар хуурч болохгүй.

Бурханы өмнө чи хүндэтгэлгүй авирлаж болохгүй. Чи Бурханы амнаас гарсан үг бүрийг дуулгавартай дагах ёстой бөгөөд Түүний үгийг сөрж, эсэргүүцэж, маргаж болохгүй.

Чи Бурханы амнаас гарсан үгийг хүссэнээрээ тайлбарлаж болохгүй. Хорон муу хүмүүсийн ов мэхтэй урхинд орохоос зайлсхийж үг хэлээ хянах ёстой.

Чамд зориулан Бурханы тогтоосон хил хязгаарыг давахаас зайлсхийж алхаагаа хянах ёстой. Хэрэв чи хил хязгаарыг давбал Бурханы байр сууринд зогсож, ихэрхүү, ихэмсэг үгээр ярихад хүрч, тэгснээр Бурханд жигшигдэх болно.

Чи Бурханы амнаас гарсан үгийг хайхрамжгүйгээр түгээж болохгүй, тэгвээс бусад хүн чамайг дооглон тохуурхаж, диаволууд чамайг маллах вий.

Чи өнөөдрийн Бурханы бүх ажлыг дуулгавартай дагах болно. Чи ойлгоогүй ч гэсэн үүнийг шүүж болохгүй; чи эрж хайж, нөхөрлөхөөс өөрийг хийж чадахгүй.

Ямар ч хүн Бурханы анхдагч байр сууринд халдах ёсгүй. Чи хүний байр сууринаас өнөөдрийн Бурханд үйлчлэхээс өөр юу ч хийж чадахгүй. Чи хүний байр сууриас өнөөдрийн Бурханд зааж болохгүй—ингэх нь буруу юм.

Бурханы гэрчилсэн хүний байранд хэн ч зогсож болохгүй; үг, үйлдэл, сэтгэлийн гүн дэх бодлоороо чи хүний байр сууринд зогсдог. Үүнийг баримтлах ёстой, энэ

бол хүний хариуцлага, үүнийг хэн ч өөрчилж болохгүй бөгөөд ингэх нь захиргааны зарлигийг зөрчинө. Үүнийг хүн бүхэн санах ёстой.

Бурхан үгээ хэлж, айлдахад удаан хугацаа зарцуулсан нь, Бурханы үгийг уншиж цээжлэх нь түүний үндсэн үүрэг гэж бодоход хүнийг хүргэсэн. Хэн ч хэрэгжүүлэлтэд анхаарал хандуулдаггүй, баримтлах ёстой зүйлээ ч та нар баримталдаггүй. Энэ нь та нарын үйлчлэлд олон бэрхшээл, асуудал авчирсан. Хэрвээ Бурханы үгийг хэрэгжүүлэхээсээ өмнө дагаж мөрдөх ёстой зүйлсээ дагаж мөрдөөгүй бол чи Бурханы жигшин, голдог хүмүүсийн нэг юм. Эдгээр хэрэгжүүлэлтийг дагаж мөрдөхдөө чи хичээнгүй, чин сэтгэлээсээ байх ёстой. Чи тэдгээрийг гав дөнгө гэж үзэлгүй, харин тушаал шиг дагаж мөрдөх ёстой. Өнөөдөр чи ямар үр дүнд хүрэх тухай санаа зовох учиргүй; товчхондоо Ариун Сүнс ингэж ажилладаг бөгөөд зөрчил гаргасан ямар ч хүн шийтгүүлэх ёстой. Ариун Сүнс сэтгэл хөдлөлгүй бөгөөд чиний одоогийн ойлголтыг анхаарч үздэггүй. Хэрвээ чи өнөөдөр Бурханд халдвал Тэр чамайг шийтгэнэ. Хэрвээ чи Өөрийнх нь эрх мэдлийн хүрээнд Түүнд халдвал Тэр чамайг өршөөхгүй. Есүсийн үгийг дагаж мөрдөхдөө хэчнээн нухацтай байдаг чинь Түүнд хамаагүй. Хэрвээ чи Бурханы өнөөдрийн тушаалуудыг зөрчвөл Тэр чамайг шийтгэж, үхэх ял онооно. Тэдгээрийг даган мөрдөхгүй байхыг чинь яаж хүлээн зөвшөөрч болох юм бэ? Бага зэргийн зовлон шаналал амсах байсан ч гэсэн чи дагаж мөрдөх ёстой! Ямар шашин, салбар, үндэстэн, урсгал байх нь хамаагүй ирээдүйд тэд бүгд эдгээр хэрэгжүүлэлтийг дагаж мөрдөх ёстой. Хэнийг ч чөлөөлж, хэнийг ч өршөөхгүй! Учир нь тэдгээр нь Ариун Сүнсний өнөөдөр хийх зүйл бөгөөд хэн ч үүнийг зөрчиж болохгүй. Хэдий тэдгээр нь агуу зүйл биш ч гэсэн хүн бүхний хийх ёстой бөгөөд дахин амилаад тэнгэр өөд гарсан Есүс хүний төлөө тогтоосон тушаалууд юм. Чиний зөв шударга эсвэл нүгэлтэй эсэхийг тодорхойлсон Есүсийн тодорхойлолт өнөөдөр Бурханд хандах хандлагаас чинь хамаардаг гэж “Зам… 7” хэлээгүй гэж үү? Хэн ч энэ санааг орхигдуулж болохгүй. Хуулийн эрин үед фарисайчууд үе дамжин Бурханд итгэдэг байсан боловч Нигүүлслийн эрин үе ирэхэд тэд Есүсийг мэдэхгүй, Түүнийг эсэргүүцэж байсан. Иймээс тэдний хийсэн бүхэн нь юу ч биш болж, талаар өнгөрөн, үйл хэргийг нь Бурхан хүлээн зөвшөөрөөгүй. Хэрвээ чи үүнийг ухан ойлгож чадвал тийм ч амархан нүгэл үйлдэхгүй. Магадгүй олон хүн өөрийгөө Бурхантай харьцуулж байсан. Бурханыг эсэргүүцэх нь ямар санагдав? Гашуун байна уу, чихэрлэг байна уу? Чи үүнийг ойлгох ёстой—мэдэхгүй дүр бүү үзүүл. Зарим хүн зүрх сэтгэлдээ итгэхгүй хэвээр байж болох юм. Гэсэн ч, Би чамд оролдоод үзэхийг зөвлөж байна—ямар амтагдаж байгааг үз. Энэ нь олон хүн үргэлж үүнийг сэжиглэхээс сэргийлэх болно. Олон хүн Бурханы үгийг уншдаг атлаа зүрх сэтгэлдээ Түүнийг нууцхан эсэргүүцдэг. Түүнийг ингэж эсэргүүцсэний дараа зүрхийг чинь хутгаар сийчиж байгаа мэт чамд санагддаггүй гэж үү? Гэр бүл чинь эв найртай биш бол бие махбод чинь тав тухгүй байх буюу хүү, охинд чинь өвчин зовлон тохиолдоно. Хэдийгээр махан бие чинь үхлээс хэлтэрсэн ч Бурханы гар чамаас хэзээ ч холдохгүй. Энэ тийм энгийн байж

болно гэж чи бодож байна уу? Ялангуяа, Бурханд ойр байгаа олон хүний хувьд үүн дээр анхаарлаа төвлөрүүлэх нь бүр ч чухал юм. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр чи үүнийг мартана, тэгээд өөрийн мэдэлгүйгээр уруу таталтад автаж, бүх зүйлийг үл анхаарах бөгөөд энэ нь нүгэл үйлдэхийн чинь эхлэл байх болно. Энэ чамд шалихгүй зүйл мэт санагдаж байна уу? Хэрвээ чи үүнийг сайн хийж чадвал чамд төгс болгуулах боломж—Бурханы өмнө очиж, Өөрийнх нь амаар залуулж чиглүүлэх боломж байна. Хэрвээ чи болгоомжгүй байвал чамд гай тохиолдоно—чи Бурханыг үл тоож, үг үйлдэл чинь замбараагүй болж, эрт орой хэзээ нэгэн цагт ширүүн салхи, хүчтэй давлагаанд туугдан одно. Эдгээр тушаалыг та нар дор бүрнээ анхаарах ёстой. Хэрвээ чи тэдгээрийг зөрчвөл Бурханы гэрчилсэн хүн чамайг яллахгүй байж магадгүй ч Бурханы Сүнс чамтай тооцоо дуусахгүй, Тэр чамайг өршөөхгүй. Зөрчлийнхөө үр дагаврыг дааж чадах уу? Тиймээс, Бурхан юу ч гэж хэлсэн чи Түүний үгийг хэрэгжүүлж, бүхий л чадлаараа дагаж мөрдөх ёстой. Энэ бол энгийн зүйл биш!

МЯНГАН ЖИЛИЙН ХААНЧЛАЛ ИРЧИХСЭН

Бурхан энэ бүлэг хүмүүст ямар ажил гүйцэтгэхийг та нар харсан уу? Мянган жилийн хаанчлалд ч гэсэн хүмүүс айлдварыг нь цаашид дагасаар байх ёстой бөгөөд ирээдүйд Бурханы айлдварууд нь Канааны сайхан газар нутаг дахь хүний амьдралыг мөн л шууд залж чиглүүлнэ гэж Бурхан нэгэнтээ хэлсэн. Мосег цөлд байхад Бурхан түүнтэй шууд ярьж, зааварчилсан. Хүмүүст эдлүүлэхийн тулд Бурхан тэнгэрээс хоол хүнс, ус болон манна илгээсэн бөгөөд өнөөдөр ч гэсэн энэ хэвээр байдаг: Бурхан хүмүүст эдлүүлэхийн тулд идэж, уух зүйлийг доош биечлэн илгээсэн ба хүмүүсийг гэсгээхийн тулд биечлэн хараал илгээсэн. Иймээс Өөрийнхөө ажлын алхам бүрийг Бурхан биечлэн гүйцэтгэдэг. Өнөөдөр хүмүүс бодит баримтуудыг эрж хайж, тэмдэг, гайхамшгуудыг эрж хайдаг ба тийм хүмүүс бүгд хаягдана, учир нь Бурханы ажил улам бүр бодитой болж байгаа. Бурхан тэнгэрээс бууж ирснийг хэн ч мэддэггүй, Бурхан хоол хүнс, тамиржуулах бэлдмэлийг тэнгэрээс доош илгээсэн гэдгийг ч бас мэддэггүй—гэхдээ Бурхан үнэхээр оршин байдаг бөгөөд хүмүүсийн төсөөлдөг Мянган жилийн хаанчлалын халуун дотно дүр зураг ч бас Бурханы хувийн айлдвар юм. Энэ нь бодит баримт бөгөөд зөвхөн үүнийг л газар дээр Бурхантай хамт хаанчлах гэж нэрлэдэг. Газар дээр Бурхантай хамт хаанчлах гэдэг нь махан биеийг хэлдэг. Махан биеийнх биш зүйл газар дээр оршин байдаггүй бөгөөд тиймээс гурав дахь тэнгэр лүү явахад анхаарлаа төвлөрүүлдэг бүх хүн дэмий юм хийж байна. Нэг өдөр бүхий л орчлон ертөнц Бурхан руу буцаж очиход сансар огторгуй даяарх Түүний ажлын төв Түүний айлдварууд дагана; өөр хаа нэгтээ Бурханы айлдварыг хүлээн авахын тулд зарим хүн утас ашиглана, зарим нь онгоцоор явна, зарим нь завиар тэнгис гатална,

мөн зарим нь лазер ашиглана. Хүн бүр бахдан биширч, хүсэн эрмэлзэх ба бүгд Бурханд ойртон ирж, Бурхан руу цугларч, бүгд Бурханд шүтэн мөргөнө—энэ бүхэн нь Бурханы үйл хэрэг байх болно. Үүнийг сана! Бурхан хэзээ ч хаа нэгтээ дахин эхлэхгүй нь гарцаагүй. Бурхан энэ баримтыг гүйцэлдүүлнэ: Тэр орчлон ертөнц даяар бүх хүнийг Өөрийнхөө өмнө ирүүлж, газар дээрх Бурханыг шүтүүлэх ба өөр газрууд дахь Түүний ажил зогсож, хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Энэ нь Иосеф шиг байх болно: Түүнд идэх юм байсан учраас хүн бүр хоол хүнс авахаар түүн рүү очиж, түүнд бөхийдөг байсан. Өлсгөлөнгөөс зайлсхийхийн тулд хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Шашны нийгэмлэг тэр чигтээ асар их өлсгөлөн амсах ба зөвхөн өнөөдрийн Бурхан л амьд усны булаг, хүний таашаалыг хангах ширгэшгүй мөнх урсах булагтай бөгөөд хүмүүс Түүн рүү очиж, Түүнд найдна. Тэр нь Бурханы үйл хэрэг илчлэгдэж, Бурхан алдрыг олж авах цаг байх болно; орчлон ертөнц даяар бүх хүн хэнд ч анзаарагдамгүй энэ “хүнд” шүтэн мөргөнө. Энэ нь Бурханы алдрын өдөр байх бус уу? Нэг өдөр ахмад пасторууд амийн усны ширгэшгүй булгаас ус хайн цахилгаан мэдээ илгээнэ. Тэд өндөр настай байх боловч өөрсдийнхөө дорд үзэж байсан энэ хүнийг шүтэн мөргөхөөр ирнэ. Тэд Түүнийг амаараа хүлээн зөвшөөрч, чин сэтгэлээсээ Түүнд итгэнэ—энэ нь тэмдэг, гайхамшиг биш гэж үү? Хаанчлал бүхэлдээ хөөрөн баярлах үе нь Бурханы алдрын өдөр байх ба та нар дээр ирж, Бурханы сайн мэдээг хүлээн авдаг хэн боловч Бурханаар ерөөгдөнө, улс орнууд, хүмүүс Бурханаар ерөөгдөж, халамжлуулна. Ирээдүйн чиглэл ийм байна: Бурханы амнаас гарсан айлдварыг олж авсан хүмүүс газар дээр алхах замтай байх бөгөөд бизнес эрхлэгчид, эрдэмтэд, сурган хүмүүжүүлэгчид, аж үйлдвэр эрхлэгчид ч бай, Бурханы үггүй хүмүүсийн хувьд ганц алхам хийхэд ч хэцүү байх бөгөөд албан хүчээр үнэн замыг эрж хайна. “Үнэнтэй бол чи дэлхий даяар алхана; үнэнгүй бол хаана ч хүрч чадахгүй” гэдгийн учир энэ юм. Бодит баримт ийм байдаг: Бүх орчлон ертөнцийг захирч, хүн төрөлхтнийг удирдаж, байлдан дагуулахын тулд Бурхан Замыг (Өөрийн бүх үгийг гэсэн утгатай) ашиглана. Бурханы ажилладаг арга барилд асар их өөрчлөлт гарна гэж хүмүүс үргэлж найдаж байгаа. Шулуухан хэлэхэд, Бурхан хүмүүсийг үгээр дамжуулан хянадаг ба чи хүссэн, хүсээгүй Түүний хэлдэг зүйлийг хийх ёстой; энэ бол бодит баримт, үүнийг бүгд дуулгавартай дагах ёстой, иймээс энэ нь бас гуйвшгүй бөгөөд бүх хүний мэддэг зүйл юм.

Ариун Сүнс хүмүүст мэдрэмж өгдөг. Бурханы үгийг уншсаны дараа хүмүүсийн сэтгэлд тогтвортой, амар амгалан санагддаг, харин Бурханы үгийг олж аваагүй хүмүүст хоосон санагддаг. Бурханы үгийн хүч чадал энэ юм. Хүмүүс тэдгээрийг унших ёстой ба уншсаныхаа дараа тэд тэжээгдэж, Бурханы үггүйгээр байж чадахгүй. Хүмүүс хар тамхи хэрэглэдэгтэй энэ нь адилхан: Энэ нь тэдэнд хүч чадал өгдөг, хэрэглэхгүй бол үүнд асар их татагдаж, ямар ч хүчгүй болдог. Энэ бол өнөөгийн хүмүүсийн дундах чиг хандлага юм. Бурханы үгийг унших нь хүмүүст хүч чадал өгдөг. Хэрвээ тэд үүнийг уншихгүй бол үлбэгэр хойрго болдог, харин

уншсаныхаа дараа “хэвтрээсээ” даруй өндийн босдог. Энэ бол Бурханы үг газар дээр эрх мэдэл эзэмшиж, Бурхан газар дэлхий дээр захирч байгаа хэрэг юм. Зарим хүн орхин явахыг хүсдэг, эсвэл Бурханы ажлаас залхдаг. Гэсэн ч тэд Бурханы үгээс салж чадахгүй; хэчнээн сул дорой ч тэд мөн л Бурханы үгээр амьдрах ёстой, хэчнээн тэрслүү ч Бурханы үгийг орхиж мөн л зүрхэлдэггүй. Бурханы үг сүр хүчээ үнэхээр харуулах үе бол Бурхан хаанчилж, эрх барих үе юм; Бурхан ингэж ажилладаг. Эцсийн эцэст энэ нь Бурханы ажилладаг арга барил бөгөөд хэн ч үүнийг орхиж болохгүй. Бурханы үг тоо томшгүй олон айл өрхөд түгж, бүгдэд мэдэгдэнэ, тэр үед л Түүний ажил орчлон ертөнц даяар түгнэ. Өөрөөр хэлбэл, хэрвээ Бурханы ажлыг бүх орчлон ертөнц даяар түгээе гэвэл Түүний үгийг түгээх ёстой. Бурханы алдрын өдөр Бурханы үг хүч чадал, эрх мэдлээ харуулна. Балар эртний үеэс өнөөдрийг хүртэлх Түүний үг нэг бүр гүйцэлдэж, биелнэ. Ийм маягаар Бурхан газар дээр алдар суугаа олж авна—өөрөөр хэлбэл, Түүний үг газар дээр хаанчилна. Хорон муу хүмүүс бүгд Бурханы амнаас гарсан үгээр гэсгээгдэж, зөв шударга хүмүүс бүгд Түүний амнаас гарсан үгээр ерөөгдөх ба бүгд Түүний амнаас гарсан үгээр тогтоогдож, бүрэн төгс болгуулна. Тэр ямар нэгэн тэмдэг, гайхамшиг ч үзүүлэхгүй; Түүний үгээр бүх зүйл гүйцэлдэж, Түүний үг бодит баримтыг бий болгоно. Газар дээрх хүн бүр Бурханы үгийг магтан тэмдэглэж, томчуул, хүүхдүүд, эрэгтэй, эмэгтэй, хөгшин, залуу бүх хүн Бурханы үгийн дор захирагдана. Бурханы үг махбодоор илэрч, тэдгээрийг тод томруун, бодитоор газар дээр харах боломжийг хүмүүст олгодог. Үг махбод болох гэдгийн утга учир энэ юм. “Үг махбод болох” баримтыг голчлон гүйцэлдүүлэхийн тулд Бурхан газар дээр ирсэн, өөрөөр хэлбэл, Өөрийнхөө үгийг махбодоос гаргахын тулд (Бурханы дуу хоолой шууд тэнгэрээс гардаг байсан Хуучин Гэрээний Мосегийн цаг үе шиг биш) Тэр ирсэн. Үүний дараа Мянган жилийн хаанчлалын эрин үед Түүний бүх үг биелж, хүмүүсийн нүдний өмнө харагдахуйц бодит баримт болох ба хүмүүс тэдгээрийг өөрсдийн нүдээр яг тэр хэвээр нь харна. Энэ бол Бурхан бие махбодтой болохын эрхэм дээд ач холбогдол юм. Өөрөөр хэлбэл, Сүнсний ажил махбодоор, үгээр гүйцэлддэг. Энэ бол “Үг махбод болох”, “Үг махбодоор илрэх” гэдгийн жинхэнэ утга учир юм. Бурхан л Сүнсний хүслийг ярьж чадах ба махбод дахь Бурхан л Сүнсний өмнөөс ярьж чадна; Бурханы үг бие махбодтой болсон Бурханаар илэрхийлэгдэж, бусад нь үүгээр замчлуулна. Хэн ч үүнээс ангид биш, тэд бүгдээрээ энэ цар хүрээн дотор оршдог. Зөвхөн эдгээр айлдвараас л хүмүүс мэддэг болж чадна; ийм маягаар олж аваагүй хүмүүс өөрсдийгөө тэнгэрийн айлдварыг олж авч чадна гэж бодож байгаа бол сэрүүн зүүдэлж байна. Бүх хүнийг үүнд бүрэн итгүүлэх нь Бурханы махбод болсон биеэс харагддаг илэрхийлэгддэг эрх мэдэл юм. Хамгийн хүндэт мэргэжилтнүүд болон шашны пасторууд хүртэл эдгээр үгийг хэлж чадахгүй. Тэд бүгд эдгээр үгэнд захирагдах ёстой ба хэн ч өөрийг эхлүүлж чадахгүй. Бурхан орчлон ертөнцийг байлдан дагуулахын тулд үг ашиглана. Тэр үүнийг Өөрийн махбод болсон биеэр хийхгүй, харин махбод болсон Бурханы амнаас гарах

айлдваруудыг ашиглан бүхий л орчлон ертөнц дэх бүх хүнийг байлдан дагуулна; энэ л Үг махбод болох явдал, мөн энэ л Үг махбодоор илрэх явдал юм. Бурхан төдийлөн их ажил хийгээгүй мэт хүмүүст санагдаж магадгүй—гэхдээ Бурханыг үгээ айлдмагц хүмүүс бүрмөсөн үнэмшиж, мэл гайхна. Бодит баримт байхгүй бол хүмүүс орилж хашхирдаг; Бурханы үг байвал тэд чимээгүй болдог. Бурхан энэ баримтыг гарцаагүй гүйцэлдүүлнэ, учир нь энэ бол Бурханы аль хэдийн тогтоосон төлөвлөгөө буюу Үг газар дээр ирсэн баримтыг гүйцэлдүүлэх явдал юм. Үнэндээ, Мянган жилийн хаанчлал газар дээр ирсэн нь Бурханы үг газар дээр ирсэн хэрэг юм гэдгийг тайлбарлах хэрэг Надад байхгүй. Шинэ Иерусалим тэнгэрээс бууж ирсэн нь Бурханы үг хүмүүсийн дунд амьдрахаар ирж, хүний үйлдэл бүрийг болон үнэн сэтгэлийн бүх бодлыг нь дагалдаж буй хэрэг юм. Энэ нь бас Бурханы гүйцэлдүүлэх баримт; Мянган жилийн хаанчлалын гоо үзэсгэлэн билээ. Энэ бол Бурханы тогтоосон төлөвлөгөө: Түүний үг газар дээр мянган жилийн турш харагдаж, Түүний бүх үйл хэргийг харуулж, газар дээрх Түүний бүх ажлыг дуусгана, үүний дараа хүн төрөлхтний энэ үе шат төгсгөлдөө очно.

БУРХАНТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА ЧИНЬ ЯМАР ВЭ?

Бурханд итгэхдээ чи Бурхантай хэвийн харилцаатай байх асуудлыг ядаж шийдвэрлэх ёстой. Бурхантай хэвийн харилцаагүй бол Бурханд итгэх итгэлийн чинь утга учир алдагддаг. Бурханы өмнө тайван байдаг зүрх сэтгэлтэй бол Бурхантай хэвийн харилцаа тогтоох бүрэн боломжтой. Бурхантай хэвийн харилцаатай байна гэдэг нь Бурханы ямар ч ажилд эргэлзэхгүй, үгүйсгэхгүй байж, Түүний ажилд захирагдаж чаддаг байна гэсэн үг юм. Энэ нь Бурханы өмнө зөв санаа зорилготой байж, өөртөө зориулан төлөвлөгөө зохиолгүй, бүх зүйл дээр Бурханы гэр бүлийн ашиг сонирхлыг анхааран үзэх гэсэн үг; мөн Бурханы шинжилтийг хүлээн зөвшөөрч, Бурханы зохицуулалтыг дуулгавартай дагах гэсэн үг юм. Чи хийж буй бүх зүйлдээ Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж чаддаг байх ёстой. Бурханы хүслийг ойлгодоггүй ч байсан гэсэн чи үүрэг, хариуцлагаа чадлынхаа хэрээр биелүүлсээр байх ёстой. Бурханы хүсэл чамд илчлэгдмэгц, үйлдвэл хожимдохгүй байх болно. Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн болоход чи хүмүүстэй ч бас хэвийн харилцаатай болно. Бурхантай хэвийн харилцаа тогтоохын тулд бүх зүйл Бурханы үгэнд үндэслэсэн байх ёстой бөгөөд Бурханы үг болон Бурханы шаарддаг зүйлийн дагуу үүргээ биелүүлж чаддаг байх ёстой, мөн үзэл бодлоо залруулж, бүх зүйл дээр үнэнийг эрж хайх ёстой. Үнэнийг ойлгох үедээ хэрэгжүүлэх ёстой, юу ч тохиолдлоо гэсэн Бурханд дуулгавартай зүрх сэтгэлээр Бурханд залбирч, эрж хайх ёстой. Ийнхүү хэрэгжүүлснээр Бурхантай хэвийн харилцаагаа хадгалж чадна. Үүргээ зохистой биелүүлэхийн зэрэгцээ бас Бурханы сонгосон хүмүүсийн амийн оролтод ашиггүй зүйл хийхгүй, ах эгч нарт

тусгүй юу ч хэлэхгүй байх баталгаа гаргах ёстой. Ядаж л мөс чанартаа сэвтэй юм хийхгүй, ичгүүртэй юм яавч хийхгүй байх ёстой. Ялангуяа, Бурханы эсрэг тэрсэлж, Бурханыг эсэргүүцдэг зүйл яавч хийхгүй байх ёстой бөгөөд чуулганы ажил, амьдралыг үймүүлдэг юу ч хийхгүй байх ёстой. Хийж буй бүхэндээ чигч шударга, хүндлүүштэй бай, үйлдэл болгоноо Бурханы өмнө үзүүлэхүйц байлга. Махан бие заримдаа сул дорой байж болох ч чи хувийн ашиг хонжооны төлөө шуналгүй, аминч, жигшүүртэй юм хийлгүй, Бурханы гэр бүлийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж, өөрийгөө үргэлж эргэцүүлж чаддаг байх ёстой. Ийм маягаар чи үргэлж Бурханы өмнө амьдарч чадна, Бурхантай харилцах харилцаа чинь тун хэвийн болно.

Чи хийдэг бүх зүйлдээ санаа зорилго чинь зөв эсэхийг шалгах ёстой. Хэрвээ чи Бурханы шаардлагын дагуу үйлдэж чаддаг бол Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн байдаг. Энэ бол хамгийн наад захын стандарт юм. Өөрийн санаа зорилгыг шалга, тэгээд буруу санаа зорилго гарч ирснийг олж мэдвэл тэдгээрийг орхиж, Бурханы үгийн дагуу үйлдэж чаддаг бай; тэгвэл чи Бурханы өмнө зөв нэгэн болох бөгөөд энэ нь эргээд Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн байгааг, мөн хийж байгаа бүхэн чинь өөрийнхөө төлөө бус, Бурханы төлөө байдаг гэдгийг харуулдаг. Чи хийдэг, хэлдэг бүхэндээ зүрх сэтгэлээ зөв байлгаж, үйлдэлдээ зөв шударга байж чаддаг бөгөөд сэтгэл хөдлөлдөө автдаггүй, өөрийн хүслийн дагуу ч үйлддэггүй байх ёстой. Эдгээр нь Бурханд итгэгчдийн биеэ авч явах ёстой зарчим юм. Жижиг зүйлс хүний санаа зорилго болон биеийн хэмжээг илчилж чадах тул Бурханаар төгс болгуулах замд орохын тулд хүн эхлээд санаа зорилго болон Бурхантай харилцах харилцаагаа засаж залруулах ёстой. Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн болсон цагт л чи Түүгээр төгс болгуулж чадна; тэр үед л чиний доторх Бурханы харьцалт, засалт, сахилгажуулалт, цэвэршүүлэлт хүссэн үр дүндээ хүрч чадна. Өөрөөр хэлбэл, хэрвээ хүмүүс зүрх сэтгэлдээ Бурханыг байлгаж, хувийн ашиг хонжоо хайлгүй, өөрсдийн хэтийн ирээдүйн талаар бодолгүй (махан биеийн тухайд), харин ч амь руу орох ачааг үүрч, үнэнийг эрэлхийлэхийн төлөө чадах бүхнээ хийж, Бурханы ажилд захирагдаж чаддаг бол—хэрвээ чи үүнийг хийж чадвал эрэлхийлдэг зорилго чинь зөв байж, Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн болно. Бурхантай харилцах харилцаагаа зөв болгох нь сүнсний аянд орох эхний алхам гэж хэлж болно. Хэдийгээр хүний хувь заяа Бурханы гарт байдаг, Бурханаар урьдчилан тогтоогдсон бөгөөд өөрөө өөрчилж чадахгүй хэдий ч Бурханаар төгс болгуулж, эсвэл авхуулж чадах эсэх нь Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн байгаа эсэхээс хамаардаг. Чамд сул дорой, эсвэл дуулгаваргүй тал байж магадгүй—гэхдээ үзэл бодол болон санаа зорилго чинь зөв байгаа цагт, мөн Бурхантай харилцах харилцаа чинь зөв, хэвийн байгаа цагт чи Бурханаар төгс болгуулах шаардлагыг хангадаг. Хэрвээ чи Бурхантай зөв харилцаатай биш, махан биеийн төлөө, эсвэл гэр бүлийнхээ төлөө үйлддэг бол хэчнээн шаргуу ажилладаг чинь хамаагүй энэ бүгд юунд ч хүргэхгүй. Хэрвээ Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн бол бусад бүх зүйлийн учир олдоно.

Бурханд итгэх итгэлийн тухай үзэл бодол чинь зөв эсэх, чи хэнд итгэдэг, хэний төлөө итгэдэг, яагаад итгэдгийг л Бурхан харахаас өөр юуг ч хардаггүй. Хэрвээ эдгээр зүйлийг тодорхой харж, үзэл бодлын хэрэгжүүлэлт чинь зөв байж чадвал аминд чинь ахиц дэвшил гарч, чи зөв замд орж чадах нь гарцаагүй. Хэрвээ Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн бус, Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодол чинь буруу бол бусад бүх зүйл талаар болох ба хэчнээн их итгэдэг байсан ч чи юу ч хүлээж авахгүй. Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн болсны дараа л махан биеийг орхиж, залбирч, зовж, тэсвэрлэж, захирагдаж, ах, эгч нартаа тусалж, Бурханы төлөө өөрийгөө илүү их зарлагадах гэх мэт үедээ чи Түүнээс магтаал хүртэнэ. Хийдэг зүйл чинь үнэ цэнтэй, ач холбогдолтой байх эсэх нь чиний санаа зорилго зөв эсэх, чиний үзэл бодол зөв зүйтэй эсэхээс хамаардаг. Өнөө үед олон хүний Бурханд итгэх итгэл нь толгойгоо гилжийлгэчхээд цаг руу харахтай адил болжээ—тэдний харах өнцөг гажсан байдаг бөгөөд нээлтээр тэдгээрийг засах ёстой. Хэрвээ энэ асуудал шийдэгдвэл бүх зүйл сайхан болно; шийдэгдэхгүй бол бүх зүйл юу ч биш болно. Зарим хүн Миний өмнө сайхан аашилдаг ч Миний ар хударгаар үргэлж эсэргүүцдэг. Эдгээр нь шударга бус, хуурмаг байдлын илрэл бөгөөд ийм хүн бол Сатаны зарц юм; тэд бол Бурханыг туршихаар ирдэг Сатаны нийтлэг биелэл юм. Хэрвээ чи Миний ажил болон Миний үгэнд захирагдаж чаддаг л бол зөв хүн мөн. Чи Бурханы үгийг идэж ууж чадаж байгаа цагт, хийдэг бүхэн чинь Бурханы өмнө үзүүлж болохуйц, хийдэг бүх зүйлдээ шударга чигч хандаж байгаа цагт, мөн ичгүүртэй эсвэл бусдын аминд хохирол учруулах зүйл хийхгүй байгаа цагт, гэрэлд амьдарч, Сатанд ашиглуулахыг зөвшөөрөхгүй байгаа цагт Бурхантай харилцах харилцаа чинь зөв зохистой байх болно.

Бурханд итгэхэд санаа зорилго, үзэл бодол чинь зөв зохистой байхыг чамаас шаарддаг; Бурханы үг, Бурханы ажил, Бурханы зохицуулсан орчин, Бурханы гэрчилсэн хүн болон бодитой Бурханы талаар чи зөв ойлголт, зөв хандлагатай байх ёстой. Чи өөрийн санаанд нийцүүлэн хэрэгжүүлж, эсвэл өөрийн өчүүхэн далд явуулгыг сэдэх ёсгүй. Чи юу ч хийсэн үнэнийг хайж, Бурханы бүтээлийн хувиар өөрийн байр сууринд зогсож, Бурханы бүх ажилд захирагдаж чаддаг байх ёстой. Хэрвээ чи Бурханаар төгс болгуулж, амийн зөв замд орохыг хүсдэг бол зүрх сэтгэл чинь үргэлж Бурханы өмнө амьдарч, замаа алдалгүй, Сатаныг дагалгүй, Сатанд ажлаа хийх ямар ч боломж өгөлгүй, Сатанаар ашиглуулахыг зөвшөөрөхгүй байх ёстой. Чи өөрийгөө Бурханд бүрмөсөн өгч, Бурханаар өөрийгөө захируулах ёстой.

Чи Сатаны зарц болохыг хүсэж байна уу? Сатанд дарлуулан мөлжүүлэхийг хүсэж байна уу? Чи Бурханаар төгс болгуулахын төлөө Бурханд итгэж, Бурханыг эрэлхийлдэг үү, эсвэл Бурханы ажилд товойлгогч болохын төлөө байдаг уу? Чи Бурханаар авхуулдаг утга учиртай амьдралыг илүүд үзэх үү, эсвэл үнэ цэнгүй, хоосон амьдралыг илүүд үзэх үү? Чи Бурханд ашиглуулахыг илүүд үзэх үү, эсвэл Сатанд ашиглуулахыг илүүд үзэх үү? Чи Бурханы үг болон үнэнээр дүүргэгдэхийг

илүүд үзэх үү, эсвэл нүгэл болон Сатанаар дүүргэгдэхийг илүүд үзэх үү? Үүнийг сайтар бодож үз. Өдөр тутмын амьдралдаа, Бурхантай харилцах харилцааг чинь хэвийн бус болгох, өөрийн хэлдэг үг, хийдэг зүйлсийг чи ойлгох ёстой, тэгээд өөрийгөө засаж залруулж, зөв арга барилд орох ёстой. Үг, үйлдэл, хөдөлгөөн нэг бүрээ, мөн бодол, санаагаа цаг ямагт шалга. Өөрийн бодит байдлыг зөв ойлгож, Ариун Сүнсний ажлын арга барилд ор. Энэ бол Бурхантай хэвийн харилцаатай байх цорын ганц арга зам юм. Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн эсэхийг үнэлснээр чи санаа зорилгоо засаж, хүний уг чанар-мөн чанарыг ойлгож, өөрийгөө үнэхээр ойлгож авч чадна, ингэснээр чи бодит туршлага руу орж, өөрийгөө үнэхээр хаяж, санаатайгаар захирагдаж чадна. Бурхантай харилцах чиний харилцаа хэвийн эсэхтэй холбоотой эдгээр хэрэг явдлыг туулахдаа чи Бурханаар төгс болгуулах боломжийг олж, Ариун Сүнсний ажлын олон байдлыг ухаарч чаддаг болно. Мөн чи Сатаны олон арга заль, хуйвалдааныг нэвт харж чаддаг болно. Энэ зам чамайг Бурханаар төгс болгуулах зүгт хөтөлдөг. Бурхантай харилцаагаа зөв болгож байгаа чинь Бурханы бүх зохицуулалтад захирагдахын төлөө, мөн бодит туршлага руу илүү гүн орж, Ариун Сүнсний илүү их ажлыг олж авахын төлөө юм. Бурхантай хэвийн харилцаатай байх явдлыг хэрэгжүүлэх үед ихэнх тохиолдолд махан биеийг хаяж, Бурхантай бодитоор хамтран ажилласнаар амжилтад хүрнэ. “Хамтран ажиллах зүрх сэтгэлгүйгээр Бурханы ажлыг хүлээн авна гэдэг хэцүү; махан бие зовохгүй бол Бурханы ерөөл гэж үгүй; сүнс тэмцэхгүй бол Сатаныг гутаана гэж байхгүй” гэдгийг чи ойлгох хэрэгтэй. Хэрвээ чи эдгээр зарчмыг хэрэгжүүлж, нэгд нэгэнгүй ойлговол Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодол чинь зөв болно. Та нар одоогийн хэрэгжүүлэлтдээ “өлсгөлөнгөө дарахын тулд талх хайдаг” сэтгэлгээг халах ёстой, мөн “бүх зүйлийг Ариун Сүнс хийдэг, хүмүүс хөндлөнгөөс оролцож чадахгүй” гэсэн сэтгэлгээг халах ёстой. Ингэж хэлдэг хүн болгон “Хүмүүс хүссэн болгоноо хийж болно, цаг нь ирэхээр Ариун Сүнс ажлаа хийнэ. Хүмүүс махан биеийг хязгаарлах буюу хамтран ажиллах хэрэггүй; хамгийн чухал нь Ариун Сүнс биднийг хөдөлгөнө” гэж боддог. Эдгээр үзэл бодол нь бүгд утгагүй. Ийм нөхцөл байдалд Ариун Сүнс ажиллаж чаддаггүй. Иймэрхүү үзэл бодол Ариун Сүнсний ажилд асар том саад болдог. Ихэнхдээ Ариун Сүнсний ажил хүмүүсийн хамтын ажиллагаагаар дамжуулан биелдэг. Хамтран ажилладаггүй, шийдэмгий бус хэдий ч зан чанар нь өөрчлөгдөж, Ариун Сүнсний ажлыг хүлээж авч, Бурханаас гэгээрэл, гэрэлтүүлэлт авахыг хүсдэг хүмүүс үнэндээ хэрээс хэтэрсэн бодолтой байна. Үүнийг “өөрийгөө өөгшүүлж, Сатаныг өршөөж байгаа хэрэг” гэж нэрлэдэг. Ийм хүмүүс Бурхантай хэвийн харилцаатай байдаггүй. Чи өөрөөсөө сатанлаг зан чанарын олон илчлэл, илрэлийг олж, Бурханы өнөөгийн шаардлагад харшилсан, өөрт байдаг аливаа хэрэгжүүлэлтийг олох хэрэгтэй. Чи одоо Сатаныг хаяж чадах уу? Бурхантай хэвийн харилцаа тогтоож, Бурханы санаа зорилгын дагуу үйлдэж, шинэ амьдралтай шинэ хүн болох хэрэгтэй. Өнгөрсөн гэм буруу дээрээ бүү саат, хэтэрхий бүү харамс, босож зогсоод Бурхантай хамтарч ажиллах

чадвартай бай, биелүүлэх ёстой үүргээ биелүүл. Ийм маягаар Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн болох болно.

Хэрвээ чи эдгээр үгийг уншсаны дараа аман дээрээ хүлээн зөвшөөрсөн гэх боловч зүрх сэтгэл чинь хөдлөөгүй хэвээр үлдэж, Бурхантай харилцах харилцаагаа хэвийн болгохоор эрэлхийлдэггүй бол Бурхантай харилцах харилцаандаа ач холбогдол өгдөггүй, үзэл бодол чинь хараахан зөв болоогүй, санаа зорилго чинь Бурханаар авхуулахад, Бурханыг алдаршуулахад чиглээгүй, харин ч Сатаны хуйвалдаанд давамгайлах боломж олгож, зорилгодоо хүрэхээр чиглэдгийг чинь энэ нь нотолдог. Ийм хүмүүс буруу санаа зорилго, алдаатай үзэл бодолтой байдаг. Бурхан юу ч хэлсэн, эсвэл яаж ч хэлсэн бай, ийм хүмүүс тун хэнэггүй байж, өчүүхэн ч өөрчлөгддөггүй. Тэдний зүрх сэтгэл ямар ч айдсыг мэдэрдэггүй, тэд ичгүүр сонжуургүй. Ийм хүн бол сүнсгүй мунхаг амьтан. Чи Бурханы айлдвар бүрийг унш, тэдгээрийг ойлгож авангуутаа хэрэгжүүл. Магадгүй махан бие чинь сул дорой, чи тэрслүү, эсэргүүцэж байсан тохиолдол байж болно; өнгөрсөнд яаж авирлаж байснаас үл хамааран энэ нь чухал биш бөгөөд өнөөдөр чиний амь боловсроход энэ нь саад болж чадахгүй. Өнөөдөр чи Бурхантай хэвийн харилцаатай байж чадаж байгаа цагт найдвар бий. Хэрвээ Бурханы үгийг унших бүрд чамд өөрчлөлт гарч, чиний амьдрал сайн тал руугаа өөрчлөгдсөнийг бусад хүн хараад хэлж чадахаар байвал Бурхантай харилцах харилцаа чинь одоо хэвийн, зөв болсныг энэ нь харуулдаг. Бурхан гэм бурууд нь үндэслэн хүмүүст ханддаггүй. Чи ойлгож, ухамсарламагцаа тэрсэлж, эсэргүүцэхээ больж чадаж л байвал Бурханд өршөөгдсөөр байх болно. Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлэх ойлголт, шийдвэр чамд байгаа үед Бурханы өмнө байх байдал чинь хэвийн болох болно. Юу ч хийж байсан, түүнийгээ хийж байхдаа дараах зүйлийг бодож үзэж байгаарай: Хэрэв би үүнийг хийвэл Бурхан юу гэж бодох бол? Энэ нь ах, эгч нарт ашиг тустай байх уу? Бурханы гэр дэх ажилд ашиг тустай байх уу? Залбирал, нөхөрлөл, үг яриа, ажил, хүмүүстэй харилцах харилцаандаа өөрийн санаа зорилгыг шинжилж, Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн эсэхийг шалга. Хэрвээ чи өөрийн санаа зорилго, бодлыг ялган таньж чаддаггүй бол чамд ялгаж салгах чадвар байхгүй бөгөөд энэ нь үнэний талаар маш бага ойлгодгийг чинь нотолдог. Хэрвээ чи Бурханы хийдэг бүхний талаар тодорхой ойлгож чаддаг, аливаа зүйлийг Түүний үгээр, Түүний талд зогсоод аливааг ухамсарлаж чаддаг бол үзэл бодол чинь зөв болсон байх болно. Тиймээс Бурхантай сайн харилцаа тогтоох нь Бурханд итгэдэг хүн бүрийн хувьд тэргүүн зэргийн чухал зүйл юм; хүн бүр үүнийг хамгийн чухал үүрэг даалгавар, амьдралынх нь хамгийн том үйл явдал хэмээн авч үзэх хэрэгтэй. Чиний хийдэг бүх зүйл Бурхантай хэвийн харилцаатай эсэхээр чинь хэмжигддэг. Хэрвээ Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн, санаа зорилго чинь зөв бол үйлд. Бурхантай харилцах хэвийн харилцаагаа хадгалахын тулд чи хувийн ашиг сонирхолдоо хохирол хүлээхээс айх ёсгүй; Сатанд давамгайлах боломж олгож болохгүй, Сатаны атгад орж болохгүй, Сатан чамайг элэг доог болгохыг зөвшөөрч болохгүй. Ийм

санаа зорилготой байх нь Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн байгаагийн илрэл бөгөөд энэ нь махан биеийн төлөө бус, харин ч сүнсний амар амгалан, Ариун Сүнсний ажлыг олж авч, Бурханы хүслийг хангахын төлөө байдаг. Зөв байдалд орохын тулд Бурхантай сайн харилцаа бий болгож, Бурханд итгэх үзэл бодлоо зөв болгох ёстой. Ингэснээр Бурхан чамайг олж авч, Үгийнхээ үр жимсийг чамд илрүүлж, чамайг улам ихээр гэгээрүүлж, гэрэлтүүлэх боломжтой. Ийм маягаар чи зөв арга барилд орсон байх болно. Бурханы өнөөдрийн үгийг үргэлжлүүлэн идэж уу, Ариун Сүнсний ажлын одоогийн арга барил руу ор, Бурханы өнөөдрийн шаардлагад нийцүүлэн үйлд, хэрэгжүүлэлтийн хуучирсан арга барилыг бүү дага, аливааг хийх хуучин аргатай бүү зууралд, өнөөдрийн ажиллах арга барилд аль болох хурдан ор. Ингэвэл Бурхантай харилцах харилцаа чинь бүрмөсөн хэвийн болж, чи Бурханд итгэх зөв замд орсон байх болно.

БОДИТ БАЙДАЛД ИЛҮҮ АНХААР

Хүн бүхэнд Бурханаар төгс болгуулах боломж байдаг, иймээс Бурханд үйлчлэх ямархуу үйлчлэл Бурханы санаа зорилготой хамгийн их нийцэлтэй байдгийг хүн бүр ойлгох ёстой. Ихэнх хүн Бурханд итгэх гэж юу гэсэн үг болохыг мэддэггүй, яагаад Бурханд итгэх ёстойгоо ч ойлгодоггүй. Өөрөөр хэлбэл, Бурханы ажил, Бурханы удирдлагын төлөвлөгөөний зорилгын талаар ихэнх нь ямар ч ойлголтгүй байдаг. Бурханд итгэх нь тэнгэр лүү явж, сүнсээ аврах явдал юм гэж дийлэнх хүмүүс өнөөг хүртэл бодсоор байдаг. Бурханд итгэхийн утга учир нь яг юу болохыг огт мэддэггүй; түүнчлэн тэдэнд Бурханы удирдлагын төлөвлөгөө дэх хамгийн чухал ажлын талаар ямар ч ойлголт байдаггүй. Янз бүрийн хувийн шалтгааны улмаас хүмүүс зүгээр л Бурханы ажлыг сонирхдоггүй, мөн Бурханы санаа зорилго, Түүний удирдлагын төлөвлөгөөний талаар огт бодож үздэггүй. Энэ урсгалд байгаа хүний хувиар хүн бүхэн, Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний зорилго юу болохыг, Бурханы аль хэдийн бодит байдал болгосон зүйлсийг, яагаад энэ бүлэг хүмүүсийг сонгосныг, тэднийг сонгосны зорилго, утга учир юу болохыг, Бурхан энэ бүлгийг юунд хүргэхийг хүсдэгийг мэдэх ёстой. Агуу улаан лууны улсад Бурхан, ийм нэг бусдаас ялгарах юмгүй бүлэг хүмүүсийг өргөж чадсан бөгөөд одоог хүртэл үргэлжлүүлэн ажиллаж, төрөл бүрийн арга замаар тэднийг шалгаж, төгс болгож, тоо томшгүй олон үг хэлж, ихээхэн ажил хэрэгжүүлж, маш олон хүчин зүтгэгчийг илгээсэн. Бурхан ганцаараа ийм их ажил гүйцэлдүүлсэн нь Түүний ажил ямар агуу ач холбогдолтой болохыг харуулдаг. Та нар одоогоор үүнийг бүрэн ухамсарлаж чаддаггүй. Иймээс та нар дээр Бурханы хийсэн ажлыг ялихгүй гэж бүү үз; энэ чинь өчүүхэн асуудал биш. Өнөөдөр та нарт Бурханы илчилсэн зүйл ч гэсэн ухаарч, ойлгохоор оролдоход чинь хангалттай. Үүнийг үнэхээр, нэгд нэггүй ойлгох юм бол л та нарын туршлага гүнзгийрч, амь чинь өсөх боломжтой. Хүмүүсийн яг одоо

ойлгож, хийж байгаа зүйл нь хэтэрхий өчүүхэн; тэд Бурханы санаа зорилгыг бүрэн биелүүлэх чадваргүй. Энэ бол хүний дутагдал бөгөөд үүргээ биелүүлж чадаагүй бүтэлгүйтэл нь, иймээс тэд хүссэн үр дүнд хүрэх чадваргүй. Олон хүн Бурханы ажлын талаар өнгөцхөн ойлголттой байдаг бөгөөд Бурханы гэрийн ажлыг хийх үедээ үүнийг үнэ цэнтэй зүйл гэж авч үзэхийг хүсдэггүй болохоор Ариун Сүнс тэдэн дээр ажиллах ямар ч аргагүй байдаг. Тэд аргацаахын тулд хийсэн дүр үзүүлж, эсвэл олонхыг дагах юм уу хүнд харуулахын тулд л ажилладаг. Өнөөдөр энэ урсгал дахь хүн бүхэн, үйлдэл, үйл хэрэгтээ чадах бүхнээ хийсэн эсэхээ болон бүх хүчин чармайлтаа зориулсан эсэхээ эргэн санах ёстой. Хүмүүс үүргээ биелүүлж огт чадаагүй нь Ариун Сүнс ажлаа хийдэггүйгээс болсон юм биш, харин хүмүүс ажлаа хийдэггүй болохоор Ариун Сүнсийг ажлаа хийх боломжгүй болгодог. Бурхан хэлэх ёстой бүх үгээ хэлж дууссан боловч хүмүүс огт хөл нийлүүлээгүй, хаа хол хоцорсон; тэд алхам бүрд ойр байж чадаагүй, Хурганы мөрийг ойрхон дагаж чадаагүй. Баримтлах ёстой зүйлээ баримтлаагүй; хэрэгжүүлэх ёстой зүйлээ хэрэгжүүлээгүй; залбирах ёстой зүйлийнхээ төлөө залбираагүй; мөн хойш тавих ёстой зүйлээ хойш тавиагүй. Тэд эдгээр зүйлийн алийг ч хийгээгүй. Иймээс зоогт оролцох тухай энэхүү яриа хий хоосон, ямар ч бодит утга учиргүй бөгөөд бүгд хүмүүсийн төсөөлөлд л байдаг. Өнөөдөр эргээд харахад, хүмүүсийг үүргээ огт биелүүлээгүй гэж хэлж болно. Бурханы Өөрөө хийж, хэлж байгаа бүхэн дээр л бүх зүйл түшиглэсээр ирсэн. Хүмүүсийн чиг үүрэг үнэхээр дэндүү өчүүхэн байсаар ирсэн; хүмүүс бол Бурхантай хэрхэн хамтран ажиллахаа мэддэггүй хэрэггүй хог новш юм. Бурхан хэдэн зуун мянган үг хэлсэн атал хүмүүс алийг нь ч хэрэгжүүлээгүй. Махан биеэ орхихоос эхлээд үзлээ хаях, бүх зүйл дээр Бурханд дуулгавартай байдлыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ ялган таних чадвараа хөгжүүлж, мэдлэг ухаан олж авах, зүрх сэтгэлдээ хүмүүсийг багтаах орон зай үүсгэхгүй байх, өөрсдийн зүрх сэтгэл дэх шүтээнүүдийг таягдан хаях, буруу санаа зорилгынхоо эсрэг тэрслэх, сэтгэл хөдлөлөөрөө үйлдэхгүй байх, аливааг өрөөсгөлөөр биш, шударгаар хийх, Бурханы ашиг сонирхлын талаар, мөн үг хэлэх үед нь бусдад үзүүлэх нөлөөллийн талаар илүү их бодох, Бурханы ажилд тустай зүйлийг илүү их хийх, хийж байгаа бүхэндээ Бурханы гэрийн ашиг тусыг бодолцох, зан байдлаа сэтгэл хөдлөлөөрөө удирдуулахгүй байх, махан биеийнхээ таалдаг зүйлсийг хаях, аминч хуучин үзлээ таягдах гэх мэтийн алийг нь ч хүмүүс хэрэгжүүлээгүй юм. Бурханы хүмүүст тавьдаг энэ бүх шаардлагын заримыг хүмүүс үнэндээ ойлгодог боловч зүгээр л тэдгээрийг хэрэгжүүлэх хүсэлгүй байдаг. Бурхан өөр юу хийж, өөрөөр яаж тэдний сэтгэлийг хөдөлгөж чадах юм бэ? Бурханы нүдэн дэх тэрслүү хөвгүүд Бурханы үгийг барьж авч, гайхан бишрэх нүүртэй байж яаж чадах юм бэ? Тэд яаж Бурханы хоол хүнсийг идэх нүүртэй байж чадах юм бэ? Хүмүүсийн мөс чанар хаана байна вэ? Тэд биелүүлэх ёстой үүргийнхээ ядаж өчүүхнийг ч биелүүлээгүй, чадах бүхнээ хийх тухайд бүр ярихын ч хэрэггүй. Тэд хоосон мөрөөдөлд амьдарч байгаа биш гэж үү? Хэрэгжүүлэлтгүйгээр бодит байдлын тухай яриа гэж байхгүй. Энэ бол ив илэрхий баримт!

Та нар илүү бодитой хичээлүүдийг судлах учиртай. Хүмүүсийн гайхан биширдэг яруу, хоосон ярианы хэрэг гэж үгүй. Мэдлэгийн тухай ярих болохоор л хүн бүр өмнөх хүнээсээ илүү мэдлэгтэй байдаг хэр нь тэд хэрэгжүүлэлтийн замгүй хэвээр л байдаг. Хэчнээн хүн хэрэгжүүлэлтийн зарчмыг ойлгосон бэ? Хэр олон хүн бодитой хичээл сурч авсан бэ? Хэн бодит байдлын талаар нөхөрлөж чадах вэ? Бурханы үгийн талаарх мэдлэгээ ярих чадвартай байна гэдэг нь жинхэнэ биеийн хэмжээтэй гэсэн үг биш; энэ нь ухаалаг, авьяастай төрснийг чинь л харуулдаг. Чи замыг зааж чадахгүй л юм бол ямар ч нэмэргүй; чи хэрэггүй хог байх болно! Чи хэрэгжүүлэх бодит замын талаар юу ч хэлж чадахгүй бол дүр үзүүлж байгаа хэрэг биш үү? Бусдад өөрийнхөө бодит туршлагаас хуваалцаж, улмаар сурч болох хичээл, дагаж болох замыг өгч чадахгүй байгаа бол худлаа жүжиглэж байгаа хэрэг биш үү? Чи хуурамч амьтан биш үү? Чамд ямар үнэ цэн байгаа юм бэ? Ийм хүн “социализмыг бий болгоход хувь нэмрээ оруулагч” бус, зөвхөн “социализмын онолыг үндэслэгчийн” үүрэг гүйцэтгэж л чадна. Бодит байдалгүй байна гэдэг нь үнэнгүй байх явдал юм. Бодит байдалгүй байна гэдэг нь ямар ч нэмэргүй байх явдал. Бодит байдалгүй байна гэдэг нь алхаж буй үхдэл байх явдал. Бодит байдалгүй байна гэдэг нь ямар ч лавлах үнэ цэнгүй “Марксист Ленинист сэтгэгч” байх явдал юм. Онол ярихаа больж, бодит, жинхэнэ, дорвитой зүйлийн талаар ярьж, жаахан “орчин үеийн урлаг” судалж, бодитой зүйл хэлж, бодит зүйлээр хувь нэмрээ оруулж, тодорхой хэмжээний зориулах сэтгэлтэй бай гэж Би нэг бүрийг чинь ятгадаг. Ярих үедээ бодит байдалтай нүүр тул; хүмүүсийг баярлуулж, өөртөө анхаарал татахын тулд хийсвэр, сүржин ярианы араас бүү хөөцөлд. Тэгэх нь ямар үнэ цэнтэй юм бэ? Хүмүүсийг өөртөө халуун дотноор хандуулах нь ямар хэрэгтэй юм бэ? Үг яриандаа бага зэрэг “урлагтай” бай, биеэ авч явахдаа арай илүү шударга бай, аливааг зохицуулахдаа арай илүү ухаалаг бай, арай илүү бодитой үг хэлж бай; үйлдэл бүртээ Бурханы гэрт ашиг тус авчрах талаар бодож бай, сэтгэл хөдлөлд автах үедээ мөс чанараа сонс, сайхан сэтгэлийг үзэн ядалтаар бүү хариул, сайн үйлсэд ачлалгүй бүү загна, хоёр нүүртэн бүү бай, эс бөгөөс чи бусдад муугаар нөлөөлөх вий. Бурханы үгийг идэж, уух үедээ чи тэдгээрийг бодит байдалтай илүү их холбо, нөхөрлөх үедээ бодитой зүйлсийн талаар илүү их ярь. Их зантай бүү бай; энэ нь Бурханыг хангалуун болгохгүй. Бусадтай харилцахдаа арай илүү хүлээцтэй бай, арай илүү найр тавьж бай, хүмүүст арай илүү уужим сэтгэлээр ханд, тэгээд “ерөнхий сайдын сэтгэлээс”[a] суралц. Муу бодол төрөх үед чи махан биеэ илүү их хаяж дад. Ажиллаж байх үедээ бодитой замын талаар илүү их ярь, хэтэрхий сүржин зүйл бүү ярь, эс бөгөөс хэлсэн үг чинь хүмүүсийн хувьд хүршгүй байх болно. Зугаа цэнгэлээ багасгаж, хувь нэмрээ ихэсгэ—амь бие хайргүй зориулах сэтгэлийг харуул. Бурханы санаа зорилгод илүү хайхрамжтай байж, мөс чанараа илүү их

[a] Ерөнхий сайдын сэтгэл: Уужуу сэтгэлтэй, өгөөмөр хүнийг дүрслэхдээ ашигладаг Хятадын сонгодог хэллэг.

сонс, Бурхан өдөр бүр та нартай яаж тэвчээртэйгээр, чин сэтгэлээсээ ярьдгийг бүү март. “Эртний лит”-ийг илүү ойр ойрхон унш. Илүү их залбирч, улам ойр ойрхон нөхөрлөл хий. Ийм будилуу байхаа боль, арай илүү эрүүл ухаан гаргаж, жаахан хэрсүү ухаантай бол. Нүгэлт гар чинь сунах үед татаж ав, хэт урт бүү сунга. Энэ нь ямар ч хэрэггүй бөгөөд чи Бурханаас хараалаас өөр юу ч авахгүй; тиймээс болгоомжтой бай. Зүрх сэтгэлдээ бусдыг өрөвд, тэгээд юм л бол зэвсэг барин дайрахаа боль. Үнэний талаарх мэдлэгийн тухай илүү их нөхөрлөж, амийн талаар илүү их ярьж, бусдад туслах сэтгэлтэй бай. Их хийж, бага ярь. Хэрэгжүүлэхэд ихийг, судалж, шинжлэхэд багыг зориул. Ариун Сүнсээр улам их хөдөлгүүлж, та нарыг төгс болгох илүү их боломжийг Бурханд олго. Хүний элементүүдийг улам их таягдан хая; та нарт аливааг хийх хүний арга зам хэтэрхий олон хэвээр байгаа бөгөөд аливааг өнгөцхөн хийдэг байдал, зан авир чинь одоо ч бусдад зэвүүцмээр байдаг. Эдгээрээс улам ихийг таягдан хая. Та нарын сэтгэл зүйн байдал одоо ч хэтэрхий жигшүүртэй; үүнийг засаж залруулахад илүү их цаг зарцуул. Та нар хүмүүст одоо ч дэндүү өндөр байр суурь өгдөг; Бурханд илүү их байр суурь өг, хэтэрхий бодлогогүй бүү загна. “Сүм” үргэлж Бурханд харьяалагдаж ирсэн бөгөөд үүнийг хүмүүс эзлэх ёсгүй. Дүгнэж хэлэхэд, зөвт байдалд илүү төвлөрч, сэтгэл хөдлөлд бага анхаар, махан биеийг таягдан хаях нь хамгийн сайн. Бодит байдлын талаар их ярьж, мэдлэгийн талаар бага ярь, чимээгүй байх нь хамгийн сайн. Хэрэгжүүлэх замын талаар их ярьж, дэмий сагсуу яриа бага ярь. Яг одоо хэрэгжүүлж эхэлбэл хамгийн сайн.

Хүмүүст тавих Бурханы шаардлага тийм ч өндөр биш. Хүмүүс хичээнгүйлэн, чин сэтгэлээсээ хэрэгжүүлж байгаа цагт “тэнцсэн үнэлгээ” авах болно. Үнэнийг хэлэхэд, үнэнийг ойлгож, мэдэж, ухаарах нь үнэнийг хэрэгжүүлэхээс илүү нарийн төвөгтэй. Эхлээд ойлгосон хэмжээгээрээ хэрэгжүүл, ухаарсан зүйлээ хэрэгжүүл. Ингэснээр чи аажмаар үнэнийг жинхэнээсээ мэдэж, ухаарч чадна. Эдгээр нь Ариун Сүнсний ажилладаг алхам, арга барил юм. Хэрвээ чи ийм маягаар дуулгавартай байдлыг хэрэгжүүлж чадахгүй бол юунд ч хүрэхгүй. Хэрвээ чи үргэлж өөрийн дураар үйлдэж, дуулгавартай байдлыг хэрэгжүүлдэггүй бол Ариун Сүнс дотор чинь ажиллах уу? Ариун Сүнс хүссэнээр чинь ажилладаг уу? Эсвэл Тэр чамд дутагдаж байгаа зүйлийн дагуу, Бурханы үгэнд үндэслэн ажилладаг уу? Хэрвээ үүнийг тодорхой мэдэхгүй бол чи үнэн-бодит байдалд орж чадахгүй. Яагаад ихэнх хүн Бурханы үгийг уншихад ихээхэн чармайлт зарцуулсан мөртөө мэдлэг төдийхөн л эзэмшиж, бодитой замын талаар дараа нь юу ч хэлж чаддаггүй юм бэ? Мэдлэг эзэмших гэдэг үнэнийг эзэмшихтэй дүйцнэ гэж чи боддог уу? Энэ чинь төөрөлдсөн үзэл бодол биш үү? Чи далайн эрэг дээрх элсний ширхэг шиг их мэдлэгийг ярьж чаддаг боловч тэдгээрийн аль нь ч ямар нэг бодитой замыг агуулдаггүй. Үүгээрээ чи хүмүүсийг хуурч байгаа биш үү? Чи бодит баталгаагүй хоосон шоу хийж байгаа бус уу? Энэ бүх зан авир хүмүүст хортой! Онол хэдий чинээ өндөр байна, төдий чинээ бодит байдлаас хол, хүмүүсийг бодит байдалд аваачих чадваргүй байдаг. Онол хэдий чинээ өндөр байна, төдий чинээ Бурханд тэрсэлж, эсэргүүцэхэд чамайг

хүргэдэг. Сүнслэг онолыг бүү эрхэмлэ, тэгээд хэрэггүй! Зарим хүн сүнслэг онолын талаар хэдэн арван жил яриад сүнслэг үзлийн суут хүмүүс болсон ч эцэст нь үнэн-бодит байдалд орж мөн л чаддаггүй. Бурханы үгийг хэрэгжүүлж, туулаагүй учраас тэдэнд хэрэгжүүлэлтийн зарчим, зам байхгүй. Ийм хүмүүс өөрсдөө үнэн-бодит байдалгүй учраас бусад хүнийг яаж Бурханд итгэх итгэлийн зөв замд оруулж чадах юм бэ? Тэд хүмүүсийг төөрүүлж л чадна. Ингэх нь бусдыг болон өөрийгөө хохироож байгаа хэрэг бус уу? Чи ядаж л яг урд чинь байгаа бодит асуудлыг шийдвэрлэж чаддаг байх ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы үгийг хэрэгжүүлж, туулж, үнэнийг хэрэгжүүлж чаддаг байх ёстой. Зөвхөн энэ л Бурханд дуулгавартай байдал. Чи амь руу орсон цагт л Бурханы төлөө ажиллахад тэнцэнэ, Бурханы төлөө чин сэтгэлээсээ зарлагадаж байгаа цагт л Бурхан чамайг сайшаана. Үргэлж бүү том мэдэгдэл хийж, гоёмсог онолын тухай ярь; ингэх нь жинхэнэ биш. Хүмүүсээр бишрүүлэхийн тулд сүнслэг онолын тухай номлох нь Бурханыг гэрчилж байгаа хэрэг биш, харин ч сайрхаж байгаа хэрэг. Ингэх нь хүмүүст ямар ч ашиг тусгүй, тэднийг босгон байгуулахгүй, сүнслэг онолыг шүтээд, үнэнийг хэрэгжүүлэхэд анхаарахгүй байхад хялбархан хүргэж чадна, ингэх нь хүмүүсийг төөрөлдүүлж байгаа хэрэг бус уу? Ийм маягаар үргэлжлүүлбэл хүмүүсийг баригдмал болгож, урхидах олон тооны хоосон онол, дүрэм журмыг нэмэгдүүлнэ; энэ нь үнэхээр ичгүүртэй хэрэг. Тиймээс бодитой зүйлийг илүү их хэлж, үнэхээр байдаг асуудлын талаар илүү их ярьж, бодит асуудлыг шийдвэрлэхийн тулд үнэнийг эрж хайхад илүү их цаг зарцуул; энэ л хамгийн чухал. Даруйхан үнэнийг хэрэгжүүлж сур: Энэ нь бодит байдалд орох зам юм. Бусад хүмүүсийн туршлага, мэдлэгийг өөрийн өмч мэт аваад, бусдаар бишрүүлэхийн тулд бүү өндөрт өргө. Чи өөрийн гэсэн амийн оролттой байх ёстой. Үнэнийг хэрэгжүүлж, Бурханыг дуулгавартай дагаж байж л амийн оролттой болно. Үүнийг хүн болгон хэрэгжүүлж, анхаарах ёстой.

Нөхөрлөдөг зүйл чинь хүмүүст алхах зам өгч чаддаг бол чамд бодит байдал байгаатай адилхан. Чи юу ч хэллээ гэсэн хүмүүсийг хэрэгжүүлэлт рүү аваачиж, тэд бүгдэд дагаж болох замыг нь өгөх ёстой. Хүмүүст зөвхөн мэдлэгтэй байх боломж бүү олго, илүү чухал нь алхах замтай байх явдал юм. Бурханд итгэхийн тулд хүмүүс Өөрийнхөө ажлаар Бурханы хөтөлдөг замаар алхах ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханд итгэх үйл явц нь Ариун Сүнсний хөтөлдөг замаар алхах үйл явц юм. Иймд чи юу ч болж байсан алхаж болох замтай байж, Бурханаар төгс болгуулах замд хөл тавих ёстой. Хэтэрхий хол бүү хоцор, мөн хэтэрхий олон зүйлд бүү анхаар. Чи Бурханы хөтөлдөг замаар саатал үүсгэлгүй алхаж чадах л юм бол Ариун Сүнсний ажлыг хүлээн авч, орох замтай болно. Үүнийг л Бурханы санаа зорилгод нийцэж, хүний үүргийг биелүүлж байна гэж тооцдог. Энэ урсгал дахь хүн болохын хувьд хүн бүр үүргээ зохистойгоор биелүүлж, хүмүүсийн хийвэл зохих зүйлийг илүү их хийж, дур зоргоороо загнахгүй байх ёстой. Ажил хэрэгжүүлж байгаа хүмүүс үгээ тодорхой болгож, дагаж байгаа хүмүүс нь бэрхшээлийг тэвчиж, дуулгавартай байхад илүү анхаарч, бүгд байр сууриа хадгалж, хэрээс хэтрэхгүй байх ёстой. Хэрхэн

хэрэгжүүлэх, ямар чиг үүргийг биелүүлэх ёстой вэ гэдэг нь хүн бүрийн зүрх сэтгэлд тодорхой байх учиртай. Ариун Сүнсний хөтөлж буй замаар яв; замаа бүү алд, бүү хазай, буруу замаар бүү ор. Та нар өнөөдрийн ажлыг тодорхой харах ёстой. Өнөөдрийн ажлын арга барилд орох нь та нарын хэрэгжүүлэх ёстой зүйл юм. Энэ нь та нарын орох ёстой эхний зүйл. Бусад зүйл дээр өөр олон үгийг бүү гарзад. Өнөөдөр Бурханы гэрийн ажлыг хийх нь та нарын хариуцлага, өнөөдрийн ажлын арга барилд орох нь та нарын үүрэг бөгөөд өнөөдрийн үнэнийг хэрэгжүүлэх нь та нарын ачаа билээ.

ТУШААЛУУДЫГ МӨРДӨЖ, ҮНЭНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Хэрэгжүүлэлтийн үеэр тушаалуудыг мөрдөх явдлыг үнэнийг хэрэгжүүлэхтэй уялдуулах ёстой. Тушаалуудыг мөрдөх зууpаа хүн үнэнийг хэрэгжүүлэх учиртай. Үнэнийг хэрэгжүүлэх үедээ хүн тушаалуудын зарчмыг зөрчиж, тушаалыг эсэргүүцэх ёсгүй; Бурханы юу л шаардсаныг чи хийх ёстой. Тушаалуудыг мөрдөх болон үнэнийг хэрэгжүүлэх нь эсрэг тэсрэг бус, харилцан уялдаатай юм. Чи үнэнийг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, тушаалын мөн чанарыг төдий чинээ их мөрдөнө. Үнэнийг хэдий чинээ их хэрэгжүүлнэ, тушаалуудад илэрхийлэгдсэн Бурханы үгийг төдий чинээ их ойлгоно. Үнэнийг хэрэгжүүлэх болон тушаалуудыг мөрдөх нь зөрчилдөөнтэй үйлдлүүд биш, харин ч хоорондоо холбоотой. Анх хүн тушаалуудыг мөрдсөний дараа л үнэнийг хэрэгжүүлж, Ариун Сүнснээс гэгээрэл олж авч чаддаг байсан боловч энэ нь Бурханы анхдагч санаа зорилго биш. Бурхан, чамаас зөвхөн сайн явдалтай байхыг биш, зүрх сэтгэлээсээ Өөрт нь шүтэн мөргөхийг шаарддаг. Гэхдээ чи тушаалуудыг ядаж өнгөцхөн ч болов мөрдөх ёстой. Туршлагаар дамжуулан хүн аажмаар Бурханы тухай илүү тодорхой ойлголттой болсныхоо дараа, Бурханы эсрэг тэрсэлж, Түүнийг эсэргүүцэхээ больж, Бурханы ажлын талаарх ямар ч эргэлзээгүй болдог. Энэ бол хүмүүс тушаалуудын мөн чанарыг сахиж чадах ганц зам юм. Тиймээс үнэнийг хэрэгжүүлэлгүй тушаалуудыг мөрдөх төдий нь үр ашиггүй бөгөөд Бурханыг бодитой шүтэн мөргөх явдлыг бүрдүүлдэггүй, учир нь чи бодитой биеийн хэмжээнд хараахан хүрээгүй. Хэрвээ чи тушаалуудыг үнэнгүйгээр мөрддөг бол энэ чинь ердөө дүрэм журмыг хатуу чанд баримтлахтай дүйцдэг. Ингэснээр тушаалууд чиний хууль болох ба амийн өсөлтөд чинь туслахгүй. Харин ч, тэдгээр нь чамд дараа болж, чамайг Хуучин Гэрээний хууль шиг ягштал хүлж, Ариун Сүнсийг дэргэдээсээ алдахад хүргэнэ. Тиймээс чи үнэнийг хэрэгжүүлснээр л тушаалуудыг үр дүнтэй мөрдөж чадах ба үнэнийг хэрэгжүүлэхийн тулд тушаалуудыг мөрдөнө. Тушаалуудыг мөрдөх явцдаа чи бүр олон үнэнийг хэрэгжүүлж, үнэнийг хэрэгжүүлэхдээ тушаалуудын утга учир үнэндээ юу болох талаар улам гүнзгий ойлголт олж авна. Хүн тушаалуудыг мөрд гэсэн Бурханы шаардлагын цаад зорилго, утга учир нь хүний төсөөлдөг шиг хүнийг дүрэм журам

мөрдүүлэх л гэсэн юм биш, харин хүний амийн оролттой холбоотой. Чиний амийн өсөлтийн хэмжээ тушаалуудыг ямар түвшинд мөрдөж чадахыг чинь тодорхойлдог. Хүнээр мөрдүүлэх гэж уг тушаалууд байдаг хэдий ч тушаалуудын мөн чанар нь хүний туршлагаар л дамжин тодорхой болдог. Тушаалуудыг сайн мөрдөнө гэдэг нь “тэд бүрмөсөн бэлэн болж, өргөгдөх л үлдсэн” гэсэн утгатай гэж ихэнх хүн боддог. Энэ нь хэрээс хэтэрсэн бодол бөгөөд Бурханы хүсэлтэй нийцдэггүй. Иймэрхүү зүйл хэлдэг хүмүүс ахиц гаргах хүсэлгүй, махан биед шунадаг. Энэ бол утгагүй үг! Энэ нь бодит байдалд таардаггүй! Тушаалуудыг бодитоор мөрдөлгүй, үнэнийг л хэрэгжүүлэх нь Бурханы хүсэл биш. Ингэдэг хүмүүс бол эрэмдэг бөгөөд өрөөсөн хөлгүй хүмүүстэй адилхан. Тушаалуудыг дүрэм журам баримталж байгаа мэт зүгээр л мөрдөж, харин үнэнийг эзэмшихгүй байх нь ч бас Бурханы хүслийг хангалуун байлгаж чадахгүй; ийнхүү үйлддэг хүмүүс өрөөсөн нүдгүй хүнтэй адил нэг төрлийн эрэмдэг юм. Хэрвээ чи тушаалуудыг сайн мөрддөг бөгөөд бодитой Бурханы талаар тодорхой ойлголт олж авсан бол чи үнэнийг эзэмшинэ гэж хэлж болно; ер нь, чи бодитой биеийн хэмжээг олж авсан байх болно. Чи хэрэгжүүлэх ёстой үнэнийг хэрэгжүүлбэл тушаалуудыг бас мөрдөх бөгөөд энэ хоёр зүйл хоорондоо зөрчилддөггүй. Үнэнийг хэрэгжүүлэх, тушаалуудыг мөрдөх гэдэг нь хоёр тогтолцоо бөгөөд аль аль нь хүний амийн туршлагын салшгүй хэсэг юм. Хүний туршлага нь тушаалуудыг мөрдөх болон үнэнийг хэрэгжүүлэх явдлын хуваагдлаас бус, нэгдлээс бүрдэх ёстой. Гэхдээ энэ хоёр зүйлийн хооронд ялгаа болон холбоо хоёул бий.

Шинэ эрин үе дэх тушаалуудын тунхаглал нь энэ урсгал дахь бүх хүн болон өнөөдөр Бурханы дуу хоолойг сонсдог бүх хүн шинэ эрин үед орсон хэмээх баримтыг гэрчлэх гэрчлэл юм. Энэ нь Бурханы ажлын шинэ эхлэл бөгөөд Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний сүүлчийн хэсгийн эхлэл билээ. Бурхан, хүн хоёр шинэ тэнгэр, шинэ газрын ертөнцөд орж, израильчуудын дунд Ехова, иудейчүүдийн дунд Есүс ажиллаж байсны яг адилаар Бурхан илүү их бодитой ажил хийж, газар дээр улам ч их, улам ч агуу ажил хийнэ гэдгийг шинэ эрин үеийн тушаалууд бэлгэддэг. Тэдгээр нь бас энэ бүлэг хүмүүс Бурханаас илүү их, илүү агуу даалгавар хүлээн авч, бодитоор хангагдаж, тэжээл, дэмжлэг, халамж, хамгаалалт хүртэх бөгөөд Бурхан тэдэнд илүү бодитой сургуулилт өгч, мөн Бурханы үгээр харьцаж, эвдэж, цэвэршүүлнэ гэдгийг бэлгэддэг. Шинэ эрин үеийн тушаалуудын учир холбогдол нэлээд гүнзгий юм. Тэдгээр нь Бурхан газар дээр үнэхээр илрэн гарах ба тэндээс бүхий л орчлон ертөнцийг байлдан дагуулж, махбодоор Өөрийн бүх алдрыг илчилнэ гэдэг санаа өгдөг. Мөн Өөрийн сонгосон бүх хүнийг төгс болгохын тулд бодитой Бурхан газар дээр илүү бодитой ажил хийх гэж байгаа гэдгийг илтгэдэг. Түүнчлэн Бурхан газар дээрх бүх зүйлийг үгээр гүйцэлдүүлж, “бие махбодтой болсон Бурхан хамгийн өндөрт мандаж, өргөмжлөгддөг агаад бүх ард түмэн, бүх улс үндэстэн агуу их Бурханыг шүтэн мөргөхөөр сөгдөнө” гэсэн баримтыг нотолно. Шинэ эрин үеийн тушаалууд нь хүнээр мөрдүүлэхийн тулд байдаг боловч, мөн тэгэх нь хүний үүрэг, хариуцлага хэдий ч тэдгээрийн төлөөлдөг

утга учир нь ганц хоёр үгээр бүрэн илэрхийлэхийн аргагүй хэтэрхий гүн гүнзгий юм. Шинэ эрин үеийн тушаалууд нь Ехова ба Есүсийн тунхагласан Хуучин Гэрээний хууль болон Шинэ Гэрээний дүрэм журмыг орлодог. Энэ бол хүний төсөөлдөг шиг энгийн хэрэг биш, илүү гүн гүнзгий хичээл юм. Шинэ эрин үеийн тушаалуудад практик учир холбогдлын тал байдаг: Тэдгээр нь Нигүүлслийн эрин үе болон Хаанчлалын эрин үеийн хоорондох холбоос болдог. Шинэ эрин үеийн тушаалууд нь хуучин эрин үеийн бүх хэрэгжүүлэлт, дүрэм журмыг болон бас Есүсийн эрин үе ба түүнээс өмнөх бүх хэрэгжүүлэлтийг төгсгөдөг. Тэдгээр нь хүнийг илүү бодитой Бурханы өмнө аваачиж, Түүгээр биечлэн төгс болгуулж эхлэх боломж олгодог; энэ нь төгс болох замын эхлэл. Тиймээс та нар шинэ эрин үеийн тушаалуудад зөв хандлага баримтлах хэрэгтэй, тэдгээрийг хааш яаш дагах юм уу, басамжилж болохгүй. Шинэ эрин үеийн тушаалууд нь нэгэн зүйлийг маш их онцолдог: Хүн өнөөдрийн бодитой Бурханыг Өөрийг нь шүтэн мөргөх ба үүнд Сүнсний мөн чанарт илүү бодитоор захирагдах явдал багтана. Эл тушаалууд нь бас, зөвт байдлын Нар болон илэрснийхээ дараа Бурхан хүнийг гэм буруутай, эсвэл зөв шударга хэмээн шүүх зарчмуудыг онцолдог. Уг тушаалуудыг ойлгох нь хэрэгжүүлэхээс амархан. Хэрвээ Бурхан хүнийг төгс болгохыг хүсвэл Өөрийн үг, удирдамжаар дамжуулан хийх ёстой ба хүн ганцхан төрөлх оюун ухаанаараа төгс байдалд хүрч чадахгүй гэдгийг үүнээс харж болно. Хүн шинэ эрин үеийн тушаалуудыг мөрдөж чадах уу, үгүй юу гэдэг нь бодитой Бурханы талаарх хүний мэдлэгтэй хамаатай. Ийм учраас чи тушаалуудыг мөрдөж чадах эсэх нь хэдхэн хоногийн дотор шийдвэрлэх асуудал биш. Энэ бол сурч мэдэх тун гүнзгий хичээл юм.

Үнэнийг хэрэгжүүлэх нь хүний амь өсөж болох зам юм. Хэрвээ үнэнийг хэрэгжүүлдэггүй бол та нарт онолоос өөр юу ч үгүй үлдэх бөгөөд бодит амьгүй байх болно. Үнэн нь хүний биеийн хэмжээний бэлгэ тэмдэг бөгөөд үнэнийг хэрэгжүүлдэг үү, үгүй юу гэдэг чинь чамд бодит биеийн хэмжээ бий эсэхтэй холбоотой. Хэрвээ чи үнэнийг хэрэгжүүлдэггүй, зөвт байдлаар үйлддэггүй, эсвэл сэтгэл хөдлөлд автаж, махан биеэ анхаардаг бол тушаалыг мөрдөхөөс хамаагүй хол байна. Энэ нь хамгийн гүн гүнзгий хичээл юм. Эрин үе тутамд хүний орж, ойлгох хэрэгтэй олон үнэн байдаг боловч эрин үе тутамд тэдгээр үнэнийг дагалддаг өөр өөр тушаал бий. Хүний хэрэгжүүлдэг үнэн нь мөн тухайн эрин үетэй холбоотой бөгөөд мөрддөг тушаалууд нь ч бас эрин үетэй холбоотой. Эрин үе тутамд өөрийн гэсэн хэрэгжүүлэх үнэн болон мөрдөх тушаалууд байдаг. Гэвч Бурханы тунхагласан янз бүрийн тушаалаас хамааран—өөрөөр хэлбэл, өөр өөр эрин үеэс хамааран—үнэнийг хэрэгжүүлэх зорилго болон үр нөлөө нь харьцангуй ялгаатай байдаг. Тушаалууд нь үнэнд үйлчилж, үнэн нь тушаалыг хадгалж хамгаалахын төлөө оршдог гэж хэлж болно. Хэрвээ зөвхөн үнэн байдаг бол Бурханы ажилд яриад байх өөрчлөлт гэж үгүй байх болно. Гэсэн хэдий ч, тушаалуудад хандсанаар хүн Ариун Сүнсний ажлын хандлагын цар хэмжээг таньж, Бурханы ажилладаг эрин үеийг мэдэж чадна. Шашинд, Хуулийн эрин үеийн хүний хэрэгжүүлж байсан үнэнийг

хэрэгжүүлж чаддаг олон хүн бий. Гэвч тэдэнд шинэ эрин үеийн тушаалууд байдаггүй бөгөөд шинэ эрин үеийн тушаалуудыг мөрдөж чаддаггүй. Тэд мөн л хуучин арга барилыг баримталж, балар эртний хүмүүс хэвээр үлддэг. Тэднийг ажлын шинэ арга барил дагалддаггүй бөгөөд тэд шинэ эрин үеийн тушаалуудыг харж чаддаггүй. Иймээс тэдэнд Бурханы ажил байдаггүй. Тэд өндөгний хоосон хальс барьсан хүнтэй адилхан; дотор нь ангаахай байхгүй бол сүнс гэж байхгүй. Тодруулбал, амь байхгүй гэсэн үг. Ийм хүмүүс шинэ эрин үед ороогүй, олон алхмын цаана хоцорчихсон. Тиймээс, хэрвээ хүмүүст хуучин эрин үеийн үнэн байдаг ч шинэ эрин үеийн тушаалууд байхгүй бол нэмэргүй. Та нарын олонх нь энэ цаг үеийн үнэнийг хэрэгжүүлдэг ч тушаалуудыг нь сахидаггүй. Та нар юу ч олж авахгүй, хэрэгжүүлдэг үнэн чинь үнэ цэнэгүй, утга учиргүй бөгөөд Бурхан та нарыг магтахгүй. Ариун Сүнсний өнөөгийн ажлын арга барил дотор үнэнийг хэрэгжүүлэх ёстой; өнөөдрийн бодитой Бурханы дуу хоолойг дагаж, үүнийг хийх ёстой. Ингэхгүйгээр бүх зүйл шүүрэн шанагаар ус утгахтай адил үр дүнгүй. Энэ бол шинэ эрин үеийн тушаалуудыг тунхаглахын бодит утга учир юм. Хүмүүс уг тушаалуудыг сахих гэж байгаа бол хамгийн наад зах нь л махбодод бий болсон бодитой Бурханыг будилж мунгиналгүй мэдэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, тушаалуудыг сахих зарчмыг хүмүүс мэдэх хэрэгтэй. Уг тушаалуудыг сахих гэдэг нь тэдгээрийг мухар сохроор юм уу, эсвэл дур зоргоороо дагана гэсэн үг биш, харин үндэс суурьтай, зорилготой, зарчимтай сахина гэсэн үг билээ. Эхлээд биелүүлэх зүйл бол үзэгдлийг чинь тод болгох явдал юм. Хэрвээ чи одоо үеийн Ариун Сүнсний ажлын талаар нэвтэрхий ойлголттой ба өнөөдрийн ажлын арга барилд орвол тушаалуудыг мөрдөх талаар аяндаа тодорхой ойлголт олж авна. Хэрвээ шинэ эрин үеийн тушаалуудын мөн чанарыг нэвт шувт харж, уг тушаалуудыг мөрдөж чадах өдөр ирвэл тэр үед чи төгс болгуулсан байх болно. Энэ нь үнэнийг хэрэгжүүлж, тушаалуудыг мөрдөхийн бодит учир холбогдол юм. Үнэнийг хэрэгжүүлж чадах эсэх чинь шинэ эрин үеийн тушаалуудын мөн чанарыг хэрхэн ойлгохоос хамаардаг. Ариун Сүнсний ажил хүнд тасралтгүй харагдаж, Бурхан хүнээс улам, улам ихийг шаардана. Тиймээс хүний үнэхээр хэрэгжүүлдэг үнэн улам олширч, илүү агуу болж, тушаалуудыг мөрдсөний үр нөлөө илүү гүн гүнзгий болно. Тиймээс та нар үнэнийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ тушаалуудыг мөрдөх ёстой. Хэн ч энэ хэрэг явдлыг огоорох ёсгүй; энэхүү шинэ эрин үед шинэ үнэн болон шинэ тушаалууд зэрэг эхлэг.

БОДИТОЙ БУРХАН БОЛ БУРХАН ӨӨРӨӨ ГЭДГИЙГ ЧИ МЭДЭХ ЁСТОЙ

Бодитой Бурханы талаар чи юу мэдэх хэрэгтэй вэ? Бодитой Бурханыг Сүнс, Хүн болон Үг бүрдүүлдэг бөгөөд энэ бол бодитой Бурханы Өөрийн жинхэнэ утга учир юм. Хэрэв чи Түүний зуршил, зан төлөвийг буюу Хүнийг л мэддэг бөгөөд

Сүнсний ажлын талаар болон Сүнс махбодод юу хийдгийг мэддэггүй бол, мөн хэрвээ чи бодитой Бурхан дахь Бурханы Сүнсний ажлыг мэдэлгүй Сүнс, Үг хоёрт л анхаарал хандуулж, зөвхөн Сүнсний өмнө залбирдаг бол бодитой Бурханыг мэддэггүй гэдгийг чинь энэ нь баталдаг. Бодитой Бурханы талаарх мэдлэг нь, Түүний үгийг мэдэж, туулах, Ариун Сүнсний ажлын дүрэм журам, зарчмуудыг болон Бурханы Сүнс махбодод хэрхэн ажилладгийг ойлгохоос бүрддэг. Түүнчлэн махбод дахь Бурханы үйлдэл бүрийг Сүнс удирддаг бөгөөд Түүний хэлсэн үг бол Сүнсний шууд илэрхийлэл юм гэдгийг мэдэх явдал ч бас үүнд багтдаг. Тиймээс, бодитой Бурханыг мэдэхийн тулд Бурхан хүн чанар болон бурханлаг чанараар хэрхэн ажилладгийг мэдэх нь хамгийн чухал; энэ нь эргээд, бүх хүний холбогддог Сүнсний илэрхийлэлтэй хамаатай юм.

Сүнсний илэрхийллийн талууд юу вэ? Бурхан заримдаа хүн чанараар, заримдаа бурханлаг чанараар ажилладаг боловч аль ч тохиолдолд Сүнс захирч байдаг. Хүмүүсийн дотор ямар сүнс байна, гадаад илэрхийлэл нь тийм байдаг. Сүнс хэвийн байдлаар ажилладаг боловч Сүнсээр удирдуулахад хоёр хэсэг бий: Нэг хэсэг нь Түүний хүн чанар дахь ажил, нөгөөх нь бурханлаг чанарын ажил юм. Үүнийг чи тодорхой мэдэх ёстой. Сүнсний ажил нөхцөл байдлаас хамааран янз бүр байдаг: Түүний хүн чанарын ажил шаардлагатай үед Сүнс энэхүү хүн чанарын ажлыг чиглүүлдэг, харин бурханлаг ажил нь шаардлагатай үед үүнийг хэрэгжүүлэхээр бурханлаг чанар нь шууд гарч ирдэг. Бурхан махбодоор ажиллаж, махбодоор илэрдэг учраас хүн чанар, бурханлаг чанарын аль алинд ажилладаг. Түүний хүн чанар дахь ажил Сүнсээр удирдуулдаг ба хүмүүсийн махан биеийн хэрэгцээг хангах, Түүнтэй харилцах тэдний харилцааг хөнгөвчлөх, тэдэнд Бурханы бодит байдал болон хэвийн байдлыг харуулах, түүнчлэн Бурханы Сүнс махбодод ирээд, хүмүүсийн дунд, хүнтэй хамт амьдарч, хүнтэй харилцаж байгаа гэдгийг харуулахын төлөө байдаг. Түүний бурханлаг чанар дахь ажил нь хүмүүсийн амийг хангаж, бүх зүйл дээр эерэг талаас нь хүмүүсийг залж чиглүүлж, хүмүүсийн зан чанарыг өөрчилж, махбод дахь Ариун Сүнсний илрэлтийг тэдэнд үнэхээр харуулахын төлөө байдаг. Үндсэндээ, хүний амийн өсөлт нь бурханлаг чанар дахь Бурханы ажил ба үгээр дамжин шууд биелдэг. Бурханы бурханлаг чанар дахь ажлыг хүлээн зөвшөөрч байж л хүмүүсийн зан чанар өөрчлөгдөх ба тэр үед л тэдний сүнс цадна; үүн дээр хүн чанарын ажил буюу Бурханы хүн чанар дахь хариулга, дэмжлэг, хангалтыг нэмсэн тохиолдолд л Бурханы ажлын үр дүнд бүрэн хүрч чадна. Өнөөдөр яригдаж буй бодитой Бурхан Өөрөө хүн чанар болон бурханлаг чанарын аль алинаар ажилладаг. Бодитой Бурханы илрэлтээр дамжуулан хэвийн хүн чанарын ажил, амьдрал болон бүрэн бурханлаг ажил нь хийгддэг. Түүний хүн чанар, бурханлаг чанар хоёр нэг болж, аль алиных нь ажил үгээр дамжин хэрэгждэг; хүн чанараар ч бай, бурханлаг чанараар ч бай, Тэр үг айлддаг. Бурхан хүн чанараар ажиллахдаа хүмүүсийг ойлгож, харилцдаг гэж хүн чанарын хэлээр ярьдаг. Түүний үг илэн далангүй, ойлгоход хялбар болохоор бүх

хүнийг хангаж чадна; хүмүүс мэдлэгтэй ч бай, боловсрол муутай ч бай, Бурханы үгийг бүгд хүлээн авч чаддаг. Бурханы бурханлаг чанар дахь ажил ч мөн үгээр хийгддэг боловч энэ нь хангалтаар дүүрэн, амиар дүүрэн байдаг бөгөөд хүний санаа холилдоогүй, хүний шилэлт сонголтыг агуулаагүй, хүн чанарын хязгаарт захирагддаггүй, ямар ч хэвийн хүн чанарын хязгаараас гадна оршдог; энэ нь мөн л махбодоор хийгддэг боловч Сүнсний шууд илэрхийлэл юм. Хэрвээ хүмүүс Бурханы хүн чанар дахь ажлыг л хүлээн зөвшөөрвөл өөрсдийгөө тодорхой хүрээнд хорих тул өчүүхэн төдий өөрчлөлт гаргахын тулд урт удаан хугацааны харьцалт, засалт, сахилгажуулалт шаардагдана. Гэхдээ Ариун Сүнс дэргэд нь байж ажиллахгүй л бол тэд үргэлж бахь байдагтаа эргэн орно; бурханлаг чанар дахь ажлаар л дамжуулан эдгээр эмгэг, дутагдлыг залруулж болох ба тэр үед л хүмүүс бүрэн төгс болгуулж чадна. Байнгын харьцалт, засалтын оронд бүх дутагдлыг залруулахад үг ашиглах, хүмүүсийн бүх байр байдлыг илчлэхэд үг ашиглах, тэдний амьдрал, үг яриа, үйлдэл бүрийг чиглүүлж, санаа зорилго, сэдлийг нь илчлэхэд үг ашиглах эерэг хангалт л шаардлагатай байдаг; энэ нь бодитой Бурханы бодит ажил юм. Тиймээс та нар бодитой Бурханд хандах хандлагаараа Түүний хүн чанарын өмнө захирагдан, Түүнийг таньж, хүлээн зөвшөөрөх ёстой, түүнчлэн чи бурханлаг ажил болон үгийг нь хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагах ёстой. Бурхан махбодоор илэрнэ гэдэг нь Бурханы Сүнсний бүх үг, ажил Түүний хэвийн хүн чанар болон Бурханы махбод болсон биеэр хийгддэг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс хүн чанарын ажлаа чиглүүлж, бурханлаг чанарын ажлыг махбодоор гүйцэтгэдэг бөгөөд бие махбодтой болсон Бурханаас чи хүн чанар дахь Бурханы ажил болон бүрэн дүүрэн бурханлаг ажлын аль алийг харж чадна; энэ бол бодитой Бурхан махбодоор гарч ирэхийн ач холбогдол билээ. Хэрвээ чи үүнийг тодорхой харж чадвал Бурханы бүх ялгаатай хэсгийг холбож чадна; мөн бурханлаг чанар дахь ажлыг нь хэтэрхий чухалчлахаа больж, хүн чанар дахь ажлыг нь хэтэрхий их үл ойшоохоо болиод, хэт туйлшрахгүй, мөн ямар ч тойруу замаар явахгүй. Ерөнхийдөө, бодитой Бурханы утга учир гэвэл Сүнсээр удирдуулсан Түүний хүн чанар болон бурханлаг чанарын ажил нь Түүний махбодоор илэрхийлэгддэг, ингэснээр хүмүүс Тэр бол тод томруун, амьд, үнэн бодитой гэдгийг харж чадна.

Хүн чанар дахь Бурханы Сүнсний ажилд шилжилтийн үеүд бий. Хүн чанараа төгс болгосноор Түүний хүн чанар Сүнсний удирдамжийг хүлээн авах боломжтой болдог, үүний дараа Түүний хүн чанар чуулганууды хангаж, хариулах чаддаг. Энэ бол Бурханы хэвийн ажлын нэг илэрхийлэл юм. Тиймээс хэрвээ чи Бурханы хүн чанар дахь ажлын зарчмыг тодорхой ойлгосон бол Бурханы хүн чанарын ажлын талаар үзэл өвөрлөх нь юу л бол. Бусад нь ямар ч бай, Бурханы Сүнс буруутна гэж үгүй. Түүний зөв, Тэр алдана гэж үгүй; ямар ч зүйлийг Тэр буруу хийхгүй. Бурханлаг ажил бол хүн чанарын хөндлөнгийн оролцоогүй Бурханы хүслийн шууд илэрхийлэл юм. Энэ нь төгс болголтыг туулалгүй Сүнснээс шууд ирдэг. Гэсэн ч үнэндээ Тэр хэвийн хүн чанараасаа үүдэн бурханлаг чанараар ажиллаж чаддаг; энэ нь ер бусын

зүйл огтхон ч биш бөгөөд хэвийн хүн хийж байгаа мэт харагддаг. Бурхан үндсэндээ махбодоор дамжуулан үгээ илэрхийлж, махбод ашиглан Бурханы Сүнсний ажлыг гүйцээхийн тулд тэнгэрээс газар луу ирсэн юм.

Өнөөдөр, бодитой Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг хэтэрхий нэг талыг барьсан хэвээр бөгөөд бие махбодтой болсон Бурханы ач холбогдлын талаарх ойлголт нь хэтэрхий өчүүхэн байсаар байна. Бурханы махбод байгаа болохоор Түүний ажил болон үгээр дамжуулан хүмүүс, Бурханы Сүнс ийм ихийг агуулдаг, Тэрээр маш баялаг гэдгийг хардаг. Гэвч үүнээс үл хамааран Бурхан махбодоор юу хийдэг, ямар зарчмаар ажилладаг, хүн чанараар юу хийдэг, бурханлаг чанараар юу хийдэг гэх мэт Бурханы гэрчлэл эцсийн дүндээ Бурханы Сүнснээс ирдэг. Хүмүүс энэ талаар мэдлэгтэй байх ёстой. Өнөөдөр чи энэ хүнд шүтэн мөргөж байж болох ч үнэндээ Сүнсийг шүтэж байгаа хэрэг бөгөөд махбодоор дамжуулан Сүнсний мөн чанарыг мэдэх, махбод дахь Сүнсний бурханлаг ажил болон хүн чанарын ажлыг мэдэх, махбод дахь Сүнсний бүх үг, айлдварыг хүлээн авах, Бурханы Сүнс махбодыг хэрхэн удирдаж, махбодоор хүч чадлаа харуулдгийг харах зэрэг нь бие махбодтой болсон Бурханы талаар хүмүүсийн олж авах ёстой наад захын мэдлэг билээ. Өөрөөр хэлбэл, хүн махбодоор дамжуулан тэнгэр дэх Сүнсийг мэдэж авдаг; хүмүүсийн дундах бодитой Бурханы Өөрийн илрэлт хүмүүсийн үзэл дэх тодорхойгүй Бурханыг арилгасан. Хүмүүс бодитой Бурханыг Өөрийг нь шүтэн мөргөснөөр Бурханд дуулгавартай байдал нь нэмэгдэж, Бурханы Сүнсний махбод дахь бурханлаг ажил болон хүн чанарын ажлаар дамжуулан хүн илчлэл, хариулгыг хүлээн авч, амь зан чанарт нь өөрчлөлт гардаг. Сүнс махбодод ирсний жинхэнэ утга учир үүнд л оршдог бөгөөд үндсэндээ ингэснээр хүмүүс Бурхантай холбогдож, Бурханд найдан, Бурханы талаарх мэдлэгийг олж авч болох юм.

Ер нь хүмүүс бодитой Бурханы талаар ямар хандлага баримтлах ёстой вэ? Бие махбодтой болсон Бурханы талаар, Үг нь махбодоор илэрсэн талаар, Бурхан махбодоор илэрсэн талаар болон бодитой Бурханы үйл хэргийн талаар чи юу мэдэх вэ? Өнөөдрийн ярианы үндсэн сэдэв юу вэ? Бие махбодтой болсон Бурхан, Үг нь махбодод ирэх, Бурхан махбодоор илрэх гэдэг нь та нарын ойлгох ёстой асуудлууд юм. Та нар биеийн хэмжээндээ болон эрин үед үндэслэн эдгээр асуудлыг аажмаар ойлгож, амийн туршлагынхаа явцад эдгээрийг тодорхой мэддэг болох ёстой. Хүмүүс Бурханы үгийг туулах үйл явц нь Бурханы үг махбодоор илрэхийг мэдэж авахтай ижил үйл явц юм. Хүмүүс Бурханы үгийг хэдий чинээ их туулна, Бурханы Сүнсийг төдий чинээ их мэдэх болно; Бурханы үгийг туулснаар хүмүүс Сүнсний ажлын зарчмыг ухаарч, бодитой Бурханыг Өөрийг нь мэдэж авдаг. Үнэндээ Бурхан хүмүүсийг төгс болгож, олж авах үедээ бодитой Бурханы үйл хэргийг тэдэнд мэдэгдэж байгаа; Тэрээр хүмүүст бие махбодтой болсон Бурханы бодит ач холбогдлыг харуулж, Бурханы Сүнс хүний өмнө үнэхээр илэрсэн гэдгийг үзүүлэхийн тулд бодитой Бурханы ажлыг ашиглаж байна. Хүмүүс Бурханаар авхуулж, Бурханаар төгс болгуулах үед бодитой Бурханы илэрхийлэл тэднийг

байлдан дагуулсан; бодитой Бурханы үг тэднийг өөрчилж, Өөрийн амийг тэдэн дотор оруулж, Тэр юу болохоор (Тэр хүн чанарын хувьд юу болох, бурханлаг чанарын хувьд юу болохын аль нь ч бай) тэднийг дүүргэж, Түүний үгийн мөн чанараар тэднийг дүүргэж, Түүний үгийг амьдран харуулахад хүмүүсийг хүргэсэн. Бурхан хүмүүсийг олж авахдаа голчлон бодитой Бурханы үг, айлдварыг ашиглах замаар хүмүүсийн дутагдалтай харьцаж, тэрслүү зан чанарыг нь шүүж, илчилдэг ба хэрэгтэй зүйлээ олж авахад тэднийг хүргэж, Бурхан хүмүүсийн дунд ирсэн гэдгийг харуулдаг. Хамгийн чухал нь, бодитой Бурханы хийдэг ажил хүн бүрийг Сатаны нөлөөнөөс аварч, бохир заваан газраас холдуулж, завхарсан зан чанарыг нь арилгадаг. Бодитой Бурханаар авхуулахын хамгийн гүн гүнзгий ач холбогдол нь бодитой Бурханыг үлгэр жишээ, үлгэр дуурайлаа болгон, хэвийн хүн чанарыг амьдран харуулж, бодитой Бурханы үг, шаардлагын дагуу өчүүхэн ч гажилт, хазайлтгүйгээр хэрэгжүүлж, Түүний хэлсэн ямар ч байдлаар хэрэгжүүлж, шаардсан болгоныг нь биелүүлж чаддаг байх явдал юм. Ийм маягаар Бурхан чамайг олж авах болно. Бурхан чамайг олж авах үед чи зөвхөн Ариун Сүнсний ажлыг эзэмшихгүй; гол нь чи бодитой Бурханы шаардлагыг амьдран харуулж чаддаг байна. Ариун Сүнсний ажилтай байлаа гээд чамд амь байгаа гэсэн үг биш. Гол нь бодитой Бурханы шаардлагын дагуу үйлдэж чадах уу, үгүй юү гэдэг бөгөөд энэ нь Бурхан чамайг олж авч чадах эсэхтэй холбоотой. Эдгээр нь махбод дахь бодитой Бурханы ажлын хамгийн том утга учир юм. Өөрөөр хэлбэл, Бурхан үнэхээр, бодитоор махбодод илэрч, хүмүүст тод томруун, амьд харагдаж, Сүнсний ажлыг махбодоор бодитоор хийж, махбодоор хүмүүст үлгэр дуурайл болсноороо бүлэг хүмүүсийг олж авдаг. Бурхан махбодод ирдэг нь үндсэндээ хүмүүст Бурханы жинхэнэ үйл хэргийг харуулах, хэлбэр дүрсгүй Сүнсийг махбодод биежүүлэх, Түүнийг харах, Түүнд хүрэх боломжийг хүмүүст олгохын төлөө байдаг. Энэ маягаар, Түүгээр бүрэн төгс болгуулсан хүмүүс Түүнийг амьдран харуулж, Түүгээр авхуулж, Түүний зүрх сэтгэлийн дагуу болно. Хэрвээ Бурхан зөвхөн тэнгэрт яриад, газар дээр бодитоор ирээгүй бол хүмүүс Бурханыг одоо ч мэдэж чадахгүй байх байв; тэд хоосон онол ашиглан Бурханы үйл хэргийг номлож л чадахаас биш, Бурханы үгийг бодит байдал болгон авч чадахгүй байх байлаа. Бурхан үндсэндээ, олж авсан хүмүүстээ үлгэр жишээ, загвар болохын тулд л газар дээр ирсэн; ийм маягаар л хүмүүс Бурханыг үнэхээр мэдэж, Бурханд хүрч, Түүнийг харж чадах ба тэр үед л Бурхан тэднийг үнэхээр олж авч чадна.

ҮНЭНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ Л БОДИТ БАЙДАЛТАЙ БОЛЖ БАЙГАА ХЭРЭГ

Бурханы үгээс жишээ татаж, ичиж зоволгүй тайлбарлаж чаддаг байх нь бодит байдалтай гэсэн үг биш; аливаа юм чиний төсөөлсөн шиг энгийн байдаггүй. Бодит байдалтай эсэх чинь чиний хэлдэг зүйлд биш, харин амьдран харуулдаг зүйлд үндэслэдэг. Бурханы үг чиний амь, төрөлхийн илэрхийлэл болсон цагт л чамайг

бодит байдалтай болсон гэж хэлж болох ба тэр үед л чамайг жинхэнэ ойлголт, бодит биеийн хэмжээтэй болсонд тооцож болно. Чи шинжилгээг удаан хугацааны туршид тэсвэрлэж чаддаг, мөн Бурханы шаарддаг төрхийг амьдран харуулж чаддаг байх ёстой. Үүнийг зүгээр нэг хэлбэрдэж болохгүй, харин чамаас аяндаа урсан гарч байх ёстой. Тэгсэн цагт л чи үнэхээр бодит байдалтай болж, тэр цагт л амийг олж авсан байх болно. Хүн бүрийн мэддэг үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтаар Би жишээ авъя: Үйлчлэл үзүүлэгчдийн талаарх хамгийн сүржин онолыг хэн ч ярьж чадах бөгөөд хүн бүр энэ сэдвийн талаар дориун сайн ойлголттой байдаг; тэд энэ талаар яриа өгдөг бөгөөд яг л тэмцээн мэт, яриа бүр нь өмнөхөөсөө сайн байдаг. Хэдий тийм ч, томоохон шалгалт туулаагүй бол хүнийг сайн гэрчлэл хийдэг гэж хэлэхэд тун хэцүү. Товчхондоо, ойлголтоос нь яг эсрэгээр хүний амьдран харуулах чадвар маш дутуу дулимаг хэвээр байгаа. Тиймээс энэ нь хүний бодит биеийн хэмжээ болох хараахан болоогүй, хүний амь болох ч бас болоогүй. Хүн ойлголтоо бодит байдал болгоогүй учраас биеийн хэмжээ нь элсэн дээр баригдсан шилтгээн мэт ганхаж, нурж унахын ирмэг дээр байсаар байна. Хүнд бодит байдал дэндүү бага байдаг, түүнээс ямар нэг бодит байдал олох бараг боломжгүй. Хүнээс аяндаа урсан гардаг бодит байдал хэтэрхий бага, амьдран харуулдаг бүх бодит байдлаа албан хүчээр хийж ирсэн. Тийм учраас Би хүнийг ямар ч бодит байдалгүй гэж хэлдэг юм. Бурханыг гэсэн хайр нь хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж хүмүүс хэлдэг боловч энэ бол ердөө л аливаа шалгалттай тулгарахаасаа өмнө тэдний хэлдэг зүйл юм. Гэнэтхэн нэг өдөр шалгалттай тулгарах үед тэдний хэлдэг зүйлс дахиад л бодит байдлаас зөрж, хүнд бодит байдал байдаггүй нь үүгээр дахин батлагдана. Үзэлд чинь үл нийцдэг, өөрийгөө хойш тавихыг чамаас шаарддаг зүйлтэй учрах бүрд тэдгээрийг чиний шалгалт гэж хэлж болно. Бурханы хүсэл илчлэгдэхээс өмнө хүн бүр хүнд хэцүү туршилт, үлэмж их шалгалт туулдаг. Чи үүнийг ухан ойлгож чадах уу? Бурхан хүмүүсийг шалгахыг хүсэхдээ бодит үнэн илчлэгдэхээс өмнө тэднээр үргэлж сонголтыг нь хийлгэдэг. Энэ нь Бурхан хүнийг шалгалтад оруулж байхдаа чамд хэзээ ч үнэнийг хэлэхгүй гэсэн үг юм; хүмүүсийг ийм байдлаар илчилдэг. Өнөөдрийн Бурханыг мэддэг эсэх, бас ямар нэг бодит байдал чамд байгаа эсэхийг харахын тулд Бурханы ажлаа гүйцэтгэдэг нэг арга нь энэ юм. Бурханы ажлын талаар чамд үнэхээр ямар ч эргэлзээ байдаггүй юу? Томоохон шалгалт тулгарахад чи үнэхээр бат зогсож чадах уу? “Ямар ч асуудал гарахгүй гэдгийг би баталж байна” гэж хэн хэлж зүрхлэх вэ? “Бусад хүмүүст эргэлзээ байгаа л байх, гэхдээ би хэзээ ч эргэлзэхгүй” гэж хэн баталж зүрхлэх вэ? Үнэн илчлэгдэхээс өмнө үргэлж сайрхдаг байсан Петрийн, шалгалт туулж байсан үетэй энэ яг адилхан юм. Энэ бол дан ганц Петрийн хувийн алдаа дутагдал биш; энэ бол хүн бүрд одоо тулгараад байгаа хамгийн том бэрхшээл юм. Хэрвээ Би Бурханы өнөөдрийн ажлын талаарх ойлголтыг чинь харахаар хэдхэн газраар орж, хэдхэн ах эгч нар дээр зочиллоо гэхэд л та нар мэдлэгийнхээ талаар гарцаагүй олон зүйл ярьж чадах байсан бөгөөд огт эргэлзсэн янзгүй харагдах байсан. Хэрвээ Би чамаас “Өнөөдрийн ажлыг Бурхан

Өөрөө гүйцэтгэж байгаа гэж чи үнэхээр ямар ч эргэлзээгүй баттай хэлж чадах уу?” гэж асуувал чи мэдээж: “Энэ бол ямар ч эргэлзээгүй Бурханы Сүнсний хийсэн ажил” гэж хариулна. Ингэж хариулмагцаа чамд мэдээж өчүүхэн төдий ч эргэлзээ төрөхгүй бөгөөд өөрийгөө бага ч болов бодит байдал олж авсан гэж санаад нэлээд додигор байх болно. Аливааг ингэж ойлгох хандлагатай хүмүүс бодит байдалгүй байдаг; өөрийгөө бодит байдалтай болсон гэж бодох тусам хүн шалгалттай тулгарахдаа бат зогсож чадахгүй. Биеэ тоосон, сагсуу хүмүүс золгүй еэ, өөрсдийгөө огт мэддэггүй хүмүүс золгүй еэ. Ийм хүмүүс ярихдаа сайн ч ярьснаа ажил хэрэг болгохдоо хамгийн муу. Бэрхшээлийн бараанаар ийм хүмүүс эргэлзэж, буцаж няцах бодол толгойд нь эргэлдэж эхэлдэг. Тэдэнд ямар ч бодит байдал байдаггүй; тэдэнд Бурханы одоо шаарддаг бодит байдлын аль нь ч байхгүй, харин шашнаас дөнгүүр онол л байдаг. Ямар ч бодит байдалгүй мөртөө зөвхөн онол ярьдаг хүмүүсийг Би хамгийн их зэвүүцдэг. Тэд ажлаа хийхдээ хамгийн чангаар хашхирдаг ч бодит байдалтай нүүр тулангуутаа сөхөрч унадаг. Тэр хүмүүст ямар ч бодит байдал байхгүйг энэ нь харуулж байгаа бус уу? Салхи, давлагаа хэчнээн ширүүн байсан ч чи толгойдоо өчүүхэн төдий ч эргэлзээ үүсгэхгүйгээр зогссоор байж чадвал, өөр хэн ч үлдээгүй байхад хүртэл бат зогсож, үгүйсгэлээс ангид байж чадвал чамайг жинхэнэ ойлголттой, үнэхээр бодит байдалтай гэж тооцно. Хэрвээ чи салхи хаашаа салхилна тийшээ хийсэж, олонхыг дагаж, бусдын яриаг тоть шиг давтаж сурвал хэчнээн уран цэцэн ярьдаг ч бай, бодит байдалтай болсны баталгаа нь энэ болохгүй. Тиймээс хоосон үг яаран хашхирахгүй байхыг Би чамд зөвлөж байна. Бурханы хийх гэж байгаа ажлыг чи мэддэг үү? Хөгөө чирч, нүүр бардам алхаж чадахаа болих гээгүй бол бас л нэг Петр шиг бүү авирла; энэ нь хэнд ч, ямар ч сайн зүйл авчрахгүй. Ихэнх хүнд бодит биеийн хэмжээ байдаггүй. Бурхан асар их ажил гүйцэтгэсэн боловч хүмүүст бодит байдлыг хүчээр авчраагүй; тодруулбал, Бурхан хэнийг ч, хэзээ ч биечлэн гэсгээж байгаагүй. Нүгэлт гараа улам хол сунган, Бурханыг дийлэхэд амархан, хүссэнээ хийж болно гэж боддог зарим хүн ийм шалгалтаар илчлэгдэж байсан. Тэд энэ төрлийн шалгалтыг ч тэсвэрлэж чаддаггүй тул илүү хүч сорьсон шалгалт болон бодит байдалтай болох талаар яриад ч хэрэггүй. Тэд ердөө л Бурханыг хуурах гэж оролдож байгаа хэрэг бус уу? Бодит байдалтай байх нь дүр үзүүлж болох зүйл биш, энэ талаар мэддэг байгаад ч бодит байдалтай болж чадахгүй. Энэ бол чиний биеийн бодит хэмжээнээс гадна бүх шалгалтыг тэсвэрлэж чадах эсэхээс хамаардаг. Чи ойлгож байна уу?

Бурхан хүмүүсээс бодит байдлын тухай зүгээр нэг ярьж чаддаг байхыг шаарддаггүй. Тийм байсан бол хэтэрхий хялбар байх бус уу? Тэгвэл Бурхан яагаад амийн оролтын тухай ярьдаг вэ? Тэр яагаад өөрчлөлтийн талаар ярьдаг вэ? Хэрвээ хүн бодит байдлын тухай хоосон ярьж л чаддаг бол зан чанарын өөрчлөлтөд хүрч чадах уу? Хаанчлалын сайн цэргүүд зөвхөн бодит байдлын тухай л ярих буюу сайрхдаг бүлэг хүн болоход бэлтгэгддэггүй, харин цаг ямагт Бурханы үгийг амьдран харуулж, ямар ч саад бартаа тулгарсан гуйвшгүй байж, ямагт

Бурханы үгийн дагуу амьдарч, дэлхий рүү буцахгүй байхаар бэлтгэгддэг. Энэ нь Бурханы ярьдаг бодит байдал бөгөөд хүнд тавьдаг Бурханы шаардлага мөн. Тиймээс Бурханы ярьсан бодит байдлыг дэндүү энгийн гэж бүү бод. Ариун Сүнснээс ирсэн гэгээрэл төдийхөн нь бодит байдалтай болохтой адилгүй: Энэ бол хүмүүсийн биеийн хэмжээ бус—энэ бол Бурханы нигүүлсэл бөгөөд хүн үүнд ямар ч хувь нэмэр оруулдаггүй. Хүн бүр Петрийн зовлонг туулах ёстой, тэр ч бүү хэл Петрийн алдрыг олж авах ёстой бөгөөд үүнийгээ Бурханы ажлыг олж авсныхаа дараа амьдран харуулдаг. Үүнийг л бодит байдал гэж нэрлэж болно. Бодит байдлын тухай ярьж чаддаг учраас бодит байдлыг олж авсан гэж бүү бод. Тэр чинь эндүүрэл. Ингэж бодох нь Бурханы хүсэлтэй нийцдэггүй бөгөөд үүнд ямар ч бодит ач холбогдол байхгүй. Цаашид ийм зүйл бүү ярь—ийм үг хэллэгийг үгүй болго! Бурханы үгийн тухай худал ойлголттой бүх хүн үл итгэгч юм. Тэдэнд ямар ч бодит мэдлэг байдаггүй, бодит биеийн хэмжээ бол бүр ч байдаггүй; тэд бол бодит байдалгүй мэдлэггүй хүмүүс юм. Өөрөөр хэлбэл Бурханы үгийн мөн чанарын гадна амьдрагсад бол үл итгэгчид билээ. Хүмүүсийн үл итгэгчид хэмээн үздэг хүмүүс нь Бурханы нүдэнд араатнууд бөгөөд үл итгэгчид хэмээн Бурханы үздэг хүмүүс нь Бурханы үгийг амиа болгоогүй хүмүүс юм. Тиймээс Бурханы үгийн бодит байдал байхгүй, Бурханы үгийг амьдран харуулж чаддаггүй хүмүүсийг үл итгэгчид гэж хэлж болно. Бурханы санаа зорилго нь хүн бүрийг Өөрийн үгийг амьдран харуулахад хүргэх—хүн бүрээр бодит байдлын тухай зүгээр нэг яриулах бус, харин бүр цаашлаад хүн бүрд Өөрийн үгийн бодит байдлыг амьдран харуулах боломж олгох юм. Хүний ухамсарладаг бодит байдал хэт өнгөц, ямар ч үнэ цэнгүй, Бурханы хүслийг гүйцэлдүүлж чадахгүй, хэтэрхий дорд, бүр дурдахын ч хэрэггүй, дэндүү дутуу дулимаг бөгөөд Бурханы шаардлагын стандартаас хэтэрхий доогуур юм. Та нарын дундаас хэн нь ойлголтынхоо талаар ярихаа л мэддэг боловч замыг зааж чаддаггүй болохыг харж, мөн хэн нь хэрэгцээгүй хог болохыг олж мэдэхийн тулд нэг бүрийг чинь сайтар нягтлан шинжлэх болно. Үүнийг цаашдаа санаж яв! Хоосон мэдлэгийн талаар бүү ярь—хэрэгжүүлэх зам, бодит байдлын тухай л ярь. Бодит мэдлэгээс бодит хэрэгжүүлэлт рүү, дараа нь хэрэгжүүлэлтээс бодитоор амьдран харуулахад шилж. Бусдад бүү сургаал айлд, бодит мэдлэгийн тухай бүү ярь. Ойлголт чинь зам бол энэ талаар чөлөөтэй ярьж болно; хэрвээ тийм биш бол амаа хамхиад, ярихаа боль! Чиний ярьдаг зүйл ямар ч хэрэггүй. Бурханыг хууран мэхэлж, бусдыг өөртөө атаархуулахын тулд чи ойлголтын талаар ярьдаг. Санаархал чинь энэ биш гэж үү? Чи зориуд бусдаар даажигнаж байгаа бус уу? Үүнд ямар нэгэн үнэ цэн байна уу? Ойлголтын тухай туулж мэдэрснийхээ дараа яривал, сайрхаж байгаа мэт санагдахгүй. Эс бөгөөс чи ихэрхүү үг чалчдаг нэгэн юм. Чамд бодит туршлагаараа даван туулж чаддаггүй олон зүйл байдаг бөгөөд чи махан биеэ эсэргүүцэж чаддаггүй, ямагт хүссэнээ хийж, Бурханы хүслийг үл хангадаг атлаа онолын ойлголтын талаар ичих нүүргүйгээр ярьсаар байдаг, чи ичгүүргүй амьтан! Бурханы үгийн тухай ойлголтоо ярих тал дээр ийм бөх зүрх гаргасаар

байдаг, чи ямар эрээ цээргүй юм бэ! Уран ярьж, сайрхах нь чиний уг чанар болж, үүнийгээ хийгээд чи бүр гаршчихсан. Чи ярихыг хүсэх болгондоо төвөггүй ярьдаг боловч хэрэгжүүлэх болохоороо нэмж хачирлах дуртай. Энэ чинь бусдыг хуурч байгаа хэрэг бус уу? Чи хүмүүсийг хуурч болох ч Бурханыг хуурч чадахгүй. Хүмүүс юм мэдэхгүй, ялган таних чадвар ч байхгүй, харин Бурхан ийм хэрэг явдалд ноцтой ханддаг, Тэр чамайг өршөөхгүй. Ах, эгч нар чинь чамайг дэмжиж, чиний ойлголтыг магтаж, чамайг биширч магадгүй ч бодит байдал чамд байхгүй бол Ариун Сүнс чамайг өршөөхгүй. Бодитой Бурхан өө сэвийг чинь ухаж төнхөхгүй байж магадгүй ч Бурханы Сүнс чамайг үл ойшоох бөгөөд үүнийг тэсвэрлэхэд чамд хангалттай хэцүү байх болно. Чи үүнд итгэж байна уу? Хэрэгжүүлэлтийн бодит байдлын тухай илүү их ярихаа чи аль хэдийн мартчихсан уу? Бодитой замуудын тухай илүү их ярихаа аль хэдийн мартчихсан уу? “Сүртэй онол, ямар ч хэрэггүй гоё чамин үг бага ярьж, одоогоос хэрэгжүүлж эхэлсэн нь хавьгүй дээр.” Эдгээр үгийг чи мартчихсан уу? Чи огт ойлгохгүй байна уу? Бурханы хүслийн талаарх ямар ч ойлголт чамд байхгүй гэж үү?

БУРХАНЫ ӨНӨӨДРИЙН АЖЛЫГ МЭДЭХ НЬ

Өнөө үед Бурханы ажлыг мэдэх нь голчлон, эцсийн өдрүүд дэх бие махбодтой болсон Бурханы үндсэн үйлчлэл юу болохыг болон Тэр юу хийхээр газар дээр ирснийг мэдэх явдал юм. Бурхан явахаасаа өмнө үлгэр жишээ үзүүлэхийн тулд (эцсийн өдрүүдэд) газар дээр ирсэн гэдгийг Би Өөрийнхөө үгэнд өмнө нь дурдсан. Бурхан энэ үлгэр жишээг хэрхэн үзүүлдэг вэ? Үг хэлснээр, бүх газар нутаг даяар ажиллаж, үг хэлснээр үзүүлдэг. Энэ бол эцсийн өдрүүд дэх Бурханы ажил юм; Тэрээр газар дэлхийг үгийн ертөнц болгохын тулд зөвхөн үг хэлдэг, ингэснээр хүн бүрийг Түүний үг хангаж, гэгээрүүлдэг, мөн хүний сүнс сэргэж, хүн үзэгдлүүдийн талаар тодорхой мэдэж авдаг. Эцсийн өдрүүдэд, бие махбодтой болсон Бурхан голчлон үг хэлэхийн тулд газар дээр ирсэн. Есүс ирэхдээ тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээж, цовдлолын золин авралын ажлыг гүйцэлдүүлсэн. Тэрээр Хуулийн эрин үеийг төгсгөж, бүх хуучин зүйлийг халсан. Есүсийн ирэлт нь Хуулийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийг авчирсан; эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурханы ирэлт нь Нигүүлслийн эрин үеийг төгсгөл болгосон юм. Тэрээр үндсэндээ Өөрийн үгийг хэлэхээр, үг ашиглан хүнийг төгс болгож, гэгээрүүлж, гэрэлтүүлэхээр, хүний зүрх сэтгэл доторх тодорхойгүй Бурханы орон зайг арилгахаар ирсэн билээ. Есүс ирэх үедээ энэ үе шатны ажлыг хийгээгүй. Есүс ирээд олон ид шид үзүүлсэн, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулсан ба цовдлолын золин авралын ажлыг хийсэн юм. Үүний үр дүнд, өөрсдийн үзэлдээ хүмүүс Бурхан ийм л байх ёстой гэж итгэдэг. Учир нь Есүс ирэхдээ хүний зүрх сэтгэлээс тодорхойгүй Бурханы дүрийг арилгах ажил хийгээгүй; харин Тэр

цовдлогдож, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээсэн. Нэг талаар, эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан нь хүний үзэл дэх тодорхойгүй Бурханы эзэлж буй орон зайг арилгадаг, ингэснээр тодорхойгүй Бурханы дүр хүний зүрх сэтгэлд байхаа больдог. Өөрийн бодит үг, бодит ажил, бүх газар нутаг даяарх Өөрийн шилжилт хөдөлгөөн, хүмүүсийн дунд хийдэг хосгүй бодитой, хэвийн ажлаар дамжуулан Тэрбээр Бурханы бодит байдлыг хүнд мэдүүлж, хүний зүрх сэтгэл дэх тодорхойгүй Бурханы байр суурийг арилгадаг. Нөгөө талаар, Бурхан хүнийг бүрэн төгс болгохын тулд Өөрийн махбодын хэлсэн үгийг ашиглаж, бүх зүйлийг гүйцэлдүүлдэг. Энэ бол эцсийн өдрүүдэд Бурханы биелүүлэх ажил юм.

Та нарын мэдэх ёстой зүйл бол:

1. Бурханы ажил ер бусын биш бөгөөд та нар энэ талаар үзэл өвөрлөх ёсгүй.
2. Бие махбодтой болсон Бурхан энэ удаа үндсэндээ ямар ажил хийхээр ирснийг та нар ойлгох ёстой.

Тэрээр өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, эсвэл ид шид үзүүлэхээр ирээгүй, мөн гэмшлийн сайн мэдээг түгээж, эсвэл хүнд золин аврал хайрлахаар ирээгүй. Яагаад гэвэл, Есүс энэ ажлыг аль хэдийн хийчихсэн бөгөөд Бурхан нэг ажлыг давтдаггүй. Өнөөдөр Бурхан Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийн бүх хэрэгжүүлэлтийг хаяхаар ирсэн. Жинхэнэ гэдгээ голчлон харуулахын тулд бодитой Бурхан ирсэн юм. Есүс ирэхдээ цөөхөн үг хэлсэн; Тэрээр голдуу ид шид үзүүлж, тэмдэг гайхамшгуудыг үйлдэж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулсан, аль эсвэл хүмүүсийг үнэмшүүлж, үнэхээр Бурхан, сэтгэл хөдлөлгүй Бурхан мөн гэдгээ хүнд харуулахын тулд зөгнөл хэлсэн. Эцэст нь Тэр цовдлолын ажлыг гүйцэлдүүлсэн. Өнөөдрийн Бурхан тэмдэг, гайхамшгуудыг харуулдаггүй, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг ч хөөн зайлуулдаггүй. Есүсийг ирэх үед Түүний хийсэн ажил Бурханы нэг хэсгийг төлөөлсөн, харин энэ удаа Бурхан хийвэл зохих ажлын үе шатыг хийхийн тулд ирсэн, учир нь Бурхан нэг ажлыг дахин давтдаггүй; Тэр бол үргэлж шинэлэг байдаг, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан юм, иймээс өнөөдөр чи бодитой Бурханы үг болон ажлыг л хардаг билээ.

Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан голчлон үгээ хэлж, хүний аминд шаардлагатай бүхнийг тайлбарлаж, хүний орох ёстой зүйлийг заан үзүүлж, Бурханы үйл хэргийг хүнд харуулж, Бурханы мэргэн ухаан, бүхнийг чадагч, гайхалтай байдлыг хүнд харуулахын тулд ирсэн юм. Бурханы ярьдаг олон арга замаар дамжуулан хүн Бурханы эрхэм дээд, агуу байдал, мөн түүнчлэн Бурханы даруу, нууцлаг байдлыг хардаг. Бурхан эрхэм дээд боловч даруу, нууцлаг бөгөөд хамгийн өчүүхэн нь болж чадна гэдгийг хүн хардаг. Түүний үгийн зарим нь шууд Сүнсний өнцгөөс хэлэгддэг, зарим нь хүний өнцгөөс шууд хэлэгддэг ба зарим нь гуравдагч хүний өнцгөөс хэлэгддэг. Үүнээс, Бурханы ажилладаг байдал асар олон янз байдгийг харж болох ба Тэр үгээр дамжуулан хүнд үүнийг харуулдаг. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил хэвийн бөгөөд бодитой байдаг, тиймээс эцсийн

өдрүүдийн бүлэг хүмүүст хамгийн том шалгалт тулгардаг. Бурханы хэвийн болон бодитой байдлаас үүдэн бүх хүн тийм шалгалтын дунд орсон; хүн Бурханы шалгалт руу унасан нь Бурханы хэвийн болон бодитой байдлаас болдог. Есүсийн эрин үед ямар ч үзэл, эсвэл шалгалт байгаагүй. Есүсийн хийсэн ихэнх ажил хүний үзэлтэй нийцэж байсан учраас хүмүүс Түүнийг дагасан ба Түүний талаар ямар ч үзэл өвөрлөөгүй. Өнөөдрийн шалгалт нь хүнд тулгарч байсан шалгалтуудаас хамгийн том нь бөгөөд энэ хүмүүс асар их гай зовлонгоос гарч ирсэн гэж хэлэх үед хэлээд буй гай зовлон нь энэ юм. Өнөөдөр, энэ хүмүүст итгэл, хайр, хатуужил, дуулгавартай байдлыг бий болгохын тулд Бурхан үгээ хэлдэг. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурханы хэлсэн үг нь хүний уг чанар-мөн чанарын дагуу, хүний зан авирын дагуу, өнөөдөр хүний орох ёстой зүйлийн дагуу байдаг. Түүний үг бодитойн сацуу хэвийн байдаг: Тэр маргаашийн тухай ярьдаггүй, өчигдрийг ч эргэж хардаггүй; Тэр өнөөдрийн орох, хэрэгжүүлэх, ойлгох ёстой зүйлийн талаар л ярьдаг. Өнөө үед тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, олон ид шид үзүүлж чадах хүн гарч ирээд, Есүс ирлээ хэмээн өөрийгөө зарлавал энэ нь Есүсийг дуурайсан муу ёрын сүнснүүдийн дүр эсгэлт байх болно. Үүнийг санаж яв! Бурхан нэг ажлаа давтдаггүй. Есүсийн ажлын үе шат аль хэдийн биелсэн ба ажлын тэрхүү үе шатыг Бурхан дахин хэзээ ч хийхгүй. Бурханы ажил хүний үзэлтэй нийцэшгүй байдаг; жишээлбэл, Хуучин Гэрээнд Мессиа ирнэ гэж зөгнөсөн боловч Есүс ирсэн нь энэ зөгнөлийн үр дүн байв. Энэ нь аль хэдийн тохиолдсон болохоор өөр Мессиа дахин ирэх нь буруу юм. Есүс аль хэдийн нэг удаа ирсэн ба энэ удаад Есүс дахин ирсэн бол буруу байх байв. Эрин үе болгонд нэг нэр байдаг, нэр болгон нь эрин үеийн шинж чанарыг агуулдаг. Хүний үзлээр бол Бурхан үргэлж тэмдэг, гайхамшиг үзүүлэх ёстой, үргэлж өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулах ёстой, үргэлж яг л Есүс шиг байх ёстой. Гэвч энэ удаа Бурхан ердөө ч тийм байдаггүй. Хэрвээ эцсийн өдрүүдэд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлсээр, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээсээр—яг Есүс шиг үйлдсэн бол нэг ажлаа давтаж байгаа хэрэг болж, Есүсийн ажил ямар ч ач холбогдол, үнэ цэнгүй байх байсан юм. Тиймээс Бурхан эрин үе бүрд ажлын нэг үе шатыг хэрэгжүүлдэг. Түүний ажлын үе шат бүрийг гүйцэлдмэгц муу ёрын сүнснүүд удалгүй дуурайдаг ба Сатан Бурханыг өсгий даран дагаж эхэлсний дараа Бурхан өөр арга барилд шилждэг. Бурхан ажлынхаа нэг үе шатыг биелүүлмэгц муу ёрын сүнснүүд үүнийг нь дуурайдаг. Та нар энэ талаар тодорхой ойлгох ёстой. Яагаад өнөөдрийн Бурханы ажил Есүсийн ажлаас өөр байдаг юм бэ? Яагаад өнөөдөр Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг зайлуулж, өвчтэйг эдгээдэггүй юм бэ? Хэрвээ Есүсийн ажил нь Хуулийн эрин үед явагдсан ажилтай адилхан байсан бол Нигүүлслийн эрин үеийн Бурханыг төлөөлж чадах байсан уу? Цовдлолын ажлыг гүйцэлдүүлж чадах байсан уу? Хэрвээ Хуулийн эрин үед байсантай адилаар Есүс сүмд орж, амралтын өдрийг сахисан бол хэн ч Түүнийг хавчихгүй байх байсан бөгөөд бүгд тойрон хүрээлэх байсан. Тэгсэн бол Тэр цовдлогдох байсан уу? Золин

авралын ажлыг гүйцэлдүүлж чадах байсан уу? Хэрвээ эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан Есүстэй адилаар тэмдэг, гайхамшгуудыг үзүүлсэн бол ямар хэрэгтэй байх юм бэ? Бурхан эцсийн өдрүүдэд Өөрийн ажлын өөр нэг хэсгийг буюу удирдлагын төлөвлөгөөнийх нь нэг хэсгийг төлөөлөх зүйлийг хийсэн цагт л хүн Бурханы талаар илүү гүн гүнзгий мэдлэгтэй болж, тэр үед л Бурханы удирдлагын төлөвлөгөө биелж чадна.

Эцсийн өдрүүдэд Бурхан голчлон Өөрийн үгийг хэлэхийн тулд ирсэн. Тэрээр Сүнсний өнцгөөс, хүний өнцгөөс болон гуравдагч хүний өнцгөөс ярьдаг; Тэрээр хэсэг хугацаанд нэг арга зам ашиглан өөр өөр байдлаар ярьдаг ба хүний үзлийг өөрчилж, хүний зүрх сэтгэлээс тодорхойгүй Бурханы дүрийг арилгахын тулд үг хэлэх арга барилыг ашигладаг. Энэ бол Бурханы хийдэг үндсэн ажил юм. Бурхан өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, ид шид үзүүлж, эд материалын ерөөлийг хүнд хайрлахаар ирсэн гэж хүн итгэдэг учраас тийм зүйлсийг хүний үзлээс арилгахын тулд Бурхан ажлын энэ үе шатыг буюу гэсгээлт, шүүлтийн ажлыг хэрэгжүүлдэг, ингэснээр хүн Бурханы бодитой болон хэвийн байдлыг мэдэж, зүрх сэтгэлээс нь Есүсийн дүр арилж, Бурханы шинэ дүрээр солигдож болох юм. Хүний доторх Бурханы дүр хуучин болмогцоо шүтээн болдог. Есүс ирээд ажлын тухайн үе шатыг биелүүлэхдээ Бурханыг бүхэлд нь төлөөлөөгүй. Тэр зарим нэг тэмдэг, гайхамшиг үзүүлж, зарим үгийг хэлж, эцэст нь цовдлогдсон юм. Тэрээр Бурханы нэг хэсгийг төлөөлж байв. Бурхан юу болох бүхнийг Тэр төлөөлж чадаагүй, харин Бурханы ажлын нэг хэсгийг хийхдээ Бурханыг төлөөлсөн юм. Учир нь, Бурхан маш агуу, маш гайхалтай, ойлгошгүй бөгөөд эрин үе болгонд ажлынхаа нэг хэсгийг л хийдэг билээ. Энэ эрин үед Бурханы хийдэг ажил нь үндсэндээ хүний амийг үгээр хангах, хүний уг чанар-мөн чанар, завхарсан зан чанарыг илчлэх, шашны үзэл, бурангуй нийгмийн үзэл бодол, хоцрогдсон үзэл бодлыг таягдан хаях явдал юм; хүний мэдлэг, соёл Бурханы үгээр илчлэгдэн цэвэрлэгдэх ёстой. Эцсийн өдрүүдэд хүнийг төгс болгохын тулд Бурхан тэмдэг гайхамшиг биш, харин үг ашигладаг. Тэрээр хүнийг ил болгож, шүүж, гэсгээж, төгс болгохын тулд Өөрийн үгийг ашигладаг, ингэснээр Бурханы үгээс хүн Бурханы мэргэн ухаан, хайр татам байдлыг харж, Бурханы зан чанарыг ойлгож авдаг, мөн Бурханы үгээр дамжуулан Бурханы үйл хэргийг хардаг. Хуулийн эрин үед Ехова Өөрийн үгээр Мосег Египетээс удирдан гаргасан ба израильчуудад зарим үгийг хэлсэн; тэр үед Бурханы үйл хэргийн нэг хэсэг нь ил тод болсон боловч хүний хэв чанар хязгаарлагдмал бөгөөд мэдлэгийг нь юу ч бүрэн дүүрэн болгож чадаагүй учраас Бурхан үргэлжлүүлэн үг хэлж, ажилласан юм. Нигүүлслийн эрин үед хүн Бурханы үйл хэргийн нэг хэсгийг дахин нэгэнтээ харсан. Есүс тэмдэг, гайхамшиг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж чадсан ба цовдлогдоод гурван өдрийн дараа амилж, хүний өмнө махбодоор харагдсан юм. Бурханы талаар хүн үүнээс илүү юу ч мэдээгүй. Бурханаас өөрт нь харуулсныг л хүн мэддэг ба хэрвээ Бурхан хүнд өөр юу ч харуулахгүй бол хүн тийм хэмжээнд л Бурханыг

хязгаарлана. Тиймээс Бурханы талаарх хүний мэдлэгийг гүнзгийрүүлэх гэсэндээ, Бурханы мөн чанарыг хүн аажмаар мэдэж аваг гэсэндээ Бурхан үргэлжлүүлэн ажилладаг. Эцсийн өдрүүдэд, хүнийг төгс болгохын тулд Бурхан Өөрийн үгийг ашигладаг. Чиний завхарсан зан чанар Бурханы үгээр илчлэгддэг бөгөөд шашны үзэл чинь Бурханы бодит байдлаар солигддог. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан үндсэндээ “Үг махбод болж, Үг махбодод ирж, Үг нь махбодоор илэрдэг” гэсэн үгийг биелүүлэхээр ирсэн бөгөөд хэрвээ чамд энэ тухай бүрэн гүйцэд мэдлэг байхгүй бол чи бат зогсож чадахгүй. Эцсийн өдрүүдэд Бурхан, Үг нь махбодоор илэрдэг ажлын үе шатыг гүйцэлдүүлэхийг үндсэндээ зорьдог бөгөөд энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөөний нэг хэсэг юм. Тиймээс та нарын мэдлэг тодорхой байх ёстой; Бурхан хэрхэн ажиллахаас үл хамааран, Өөрийг нь хязгаарлахыг Бурхан хүнд зөвшөөрдөггүй. Хэрвээ Бурхан эцсийн өдрүүдэд энэ ажлыг хийгээгүй бол Түүний талаарх хүний мэдлэг цааш ахиж чадахгүй. Бурхан цовдлогдож, Содомыг устгаж чадна, мөн Есүс үхлээс амилж, Петрт харагдаж чадна гэдгийг л чи мэдэх байсан… Гэхдээ чи Бурханы үг бүхнийг гүйцэлдүүлж, хүнийг байлдан дагуулж чадна гэж хэзээ ч хэлэхгүй. Бурханы үгийг туулснаар л чи тийм мэдлэгийн талаар ярьж чадна, Бурханы ажлыг туулах тусам Түүний талаарх мэдлэг чинь төдий чинээ бүрэн гүйцэд болно. Тэр үед л чи Бурханыг өөрийн үзэл дотор хязгаарлахаа болино. Хүн Бурханы ажлыг туулснаар л Түүнийг мэдэж авдаг; Бурханыг мэдэж авах өөр зөв арга зам гэж үгүй. Өнөөдөр олон хүн юу ч хийлгүй зүгээр л тэмдэг, гайхамшгууд болон агуу гамшгийн цаг үеийг харахаар хүлээдэг. Чи Бурханд итгэдэг үү, эсвэл агуу гамшигт итгэдэг үү? Агуу гамшиг ирэх үед хэтэрхий оройтсон байх бөгөөд хэрвээ Бурхан агуу гамшиг илгээхгүй бол Тэр тэгээд Бурхан биш гэж үү? Чи тэмдэг, гайхамшгуудад итгэдэг үү, эсвэл Бурханд Өөрт нь итгэдэг үү? Есүс бусдад дооглуулж байх үедээ тэмдэг, гайхамшиг үзүүлээгүй, гэхдээ Тэр Бурхан байсан бус уу? Чи тэмдэг, гайхамшгуудад итгэдэг үү, эсвэл Бурханы мөн чанарт итгэдэг үү? Бурханд итгэх итгэлийн талаарх хүний үзэл бодол буруу! Хуулийн эрин үед Ехова олон үг хэлсэн боловч өнөөдөр ч гэсэн тэдгээрийн зарим нь хараахан биелээгүй байгаа. Ехова бол Бурхан биш байсан гэж чи хэлж чадах уу?

Эцсийн өдрүүдэд Бурхан үндсэндээ “Үг махбод болдог” гэх баримтыг биелүүлдэг гэдгийг өнөөдөр та бүхэн тодорхой мэдэж байх ёстой. Газар дээрх бодит ажлаараа дамжуулан Тэрээр, Түүнийг мэдэж, Түүнтэй харилцаж, Түүний бодит үйл хэргийг харахад хүнийг хүргэдэг. Тэрээр тэмдэг, гайхамшиг үзүүлж чадна, бас тэгж чадахгүй үе ч Түүнд байдаг; энэ нь эрин үеэс хамаардаг гэдгийг хүнд тодорхой ойлгуулдаг. Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадваргүй байдаг юм биш, харин хийгдэх ажлын дагуу, мөн эрин үеийн дагуу ажиллах арга замаа өөрчилдөг гэдгийг чи үүнээс харж болно. Ажлын одоогийн үе шатанд Тэр тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй; Тэрээр Есүсийн эрин үед зарим тэмдэг, гайхамшгийг үзүүлж байсан нь тухайн эрин үе дэх Түүний ажил өөр байснаас болсон юм. Бурхан

өнөөдөр тэр ажлыг хийдэггүй ба зарим хүн Түүнийг тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадваргүй гэж итгэдэг, аль эсвэл тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй л бол Тэр Бурхан биш гэж боддог. Энэ нь төөрөгдөл биш гэж үү? Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлж чаддаг боловч өөр эрин үед ажиллаж байгаа тул тийм ажил хийдэггүй. Энэ нь өөр эрин үе учраас, мөн Бурханы ажлын өөр үе шат учраас Бурханы ил тод болгох үйл хэрэг нь ч бас өөр байдаг. Бурханд итгэх хүний итгэл бол тэмдэг, гайхамшигт итгэх итгэл биш, ид шидэд итгэх итгэл ч биш, харин шинэ эрин үе дэх Түүний бодит ажилд итгэх итгэл билээ. Бурханы ажилладаг байдлаар дамжуулан хүн Бурханыг мэдэж авдаг ба энэ мэдлэг нь Бурханд итгэх итгэлийг буюу Бурханы ажил болон үйл хэрэгт итгэх итгэлийг хүнд төрүүлдэг. Ажлын энэ үе шатанд Бурхан үндсэндээ үг хэлдэг. Тэмдэг, гайхамшгуудыг харна гэж бүү хүлээ; чи нэгийг ч харахгүй! Учир нь чи Нигүүлслийн эрин үед төрөөгүй. Хэрвээ тэр үед төрсөн бол чи тэмдэг, гайхамшгийг харах байсан, гэхдээ эцсийн өдрүүдэд төрсөн тул Бурханы бодит, хэвийн байдлыг л харж чадна. Эцсийн өдрүүдэд ер бусын Есүсийг харна гэж бүү хүлээ. Чи хэвийн хүнээс ямар ч ялгаагүй бие махбодтой болсон бодитой Бурханыг л харж чадна. Эрин үе болгонд Бурхан өөр өөр үйл хэргийг ил болгодог. Эрин үе бүрд Тэрээр Бурханы үйл хэргийн нэг хэсгийг ил болгодог ба эрин үе бүрийн ажил нь Бурханы зан чанарын нэг хэсгийг төлөөлж, Бурханы үйл хэргийн нэг хэсгийг төлөөлдөг. Түүний ил тод болгодог үйл хэрэг ажиллаж буй эрин үетэй нь хамт өөрчлөгддөг боловч тэдгээр нь бүгд Бурханы талаарх илүү гүнзгий мэдлэгийг, Бурханд итгэх илүү ул суурьтай, илүү жинхэнэ итгэлийг хүнд өгдөг. Бурханы бүх үйл хэргээс болж, мөн Бурхан маш гайхалтай, маш агуу, төгс хүчит, ойлгошгүй байдгаас болж хүн Бурханд итгэдэг. Бурхан тэмдэг, гайхамшгуудыг үйлдэж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж чаддаг учраас л Түүнд итгэдэг бол үзэл бодол чинь буруу байгаа бөгөөд зарим хүн чамд “Муу ёрын сүнснүүд ч бас тийм зүйл хийж чаддаг бус уу?” хэмээн хэлнэ. Энэ нь Бурханы дүрийг Сатаны дүртэй андуурсан хэрэг болох биш үү? Өнөөдөр, Бурханы олон үйл хэрэг болон хийдэг ажлынх нь асар их хэмжээ, үгээ хэлдэг олон арга замаас болж хүн Бурханд итгэдэг. Хүнийг байлдан дагуулж, төгс болгохын тулд Бурхан Өөрийн айлдварыг ашигладаг. Тэр тэмдэг, гайхамшиг үзүүлж чаддагаас болж биш, харин олон үйл хэргээс нь болж хүн Бурханд итгэдэг; үйл хэргийг нь хардаг учраас л хүн Бурханыг мэдэж авдаг. Бурханы бодитой үйл хэрэг, Тэр хэрхэн ажилладаг, ямар ухаалаг арга барил хэрэглэдэг, хэрхэн үг хэлдэг, хүнийг хэрхэн төгс болгодгийг мэдсэнээр—зөвхөн эдгээр талыг мэдсэнээр л чи Бурханы бодит байдлыг ухамсарлаж, Түүний зан чанарыг ойлгож, Тэр юунд дуртай, юуг үзэн яддаг, хүн дээр хэрхэн ажилладгийг ойлгож чадна. Бурханы дуртай, дургүй зүйлсийг ойлгосноор чи эерэг, сөрөг зүйлсийг ялгаж чадах ба Бурханы талаарх мэдлэгээр дамжуулан аминд чинь ахиц дэвшил гардаг. Товчхондоо, чи Бурханы ажлыг мэддэг болох ёстой бөгөөд Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлоо засах ёстой.

БУРХАНЫ АЖИЛ ХҮНИЙ ТӨСӨӨЛДӨГ ШИГ ЭНГИЙН ҮҮ?

Бурханд итгэгчийн хувьд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг болон өнөөдөр чамд хийдэг Бурханы төлөвлөсөн ажлыг хүлээн авснаараа Бурханаас үнэхээр агуу өргөмжлөл, авралыг хүртсэн гэдгээ та нар хүн бүрчлэн ойлгох ёстой. Бүхий л орчлон ертөнц даяарх Бурханы бүх ажил зөвхөн энэ бүлэг хүмүүс дээр төвлөрсөн. Тэрээр та нарын төлөө бүхнээ золиосолсон; Тэрээр орчлон ертөнц даяарх Сүнсний бүх ажлыг буцаан авч, та нарт өгсөн. Тийм учраас та нар бол хувьтай хүмүүс. Түүнчлэн Тэрээр алдар суугаа Өөрийн сонгосон хүмүүс болох Израилиас та нар луу шилжүүлсэн, Өөрийн төлөвлөгөөний зорилгыг энэ бүлэг хүнээр дамжуулан бүрэн харуулна. Тиймээс та нар бол Бурханы өвийг хүлээн авах хүмүүс, бүр түүгээр ч барахгүй Бурханы алдрын өв залгамжлагчид билээ. Магадгүй та бүхэн эдгээр үгийг санаж байгаа байх: “Учир нь цаг зуурын хөнгөн зовлон маань бидэнд зориулан алдрын мөнхийн жинг үлэмж арвин болгодог.” Урьд нь та нар бүгд энэ үгийг сонссон атлаа хэн ч энэ үгийн жинхэнэ утгыг ойлгоогүй. Өнөөдөр тэдгээрийн бодит ач холбогдлыг та нар сайн мэднэ. Бурхан эцсийн өдрүүдэд эдгээр үгийг биелүүлнэ, эдгээр нь агуу улаан лууны цагариглан хэвтэж байдаг газар нутагт харгисаар хяхан хавчсан хүмүүс дээр нь биелэх болно. Агуу улаан луу Бурханыг хавчдаг, Бурханы дайсан тул энэ газар нутагт Бурханд итгэдэг хүмүүс ийнхүү доромжлол, хавчлагад өртдөг бөгөөд эдгээр үг энэ бүлэг хүмүүс, та нарт биелдэг. Бурханыг эсэргүүцдэг газарт эхлүүлсэн учраас Бурханы бүх ажилд асар их саад тотгор учирч, Түүний олон үгийг гүйцэлдүүлэхэд цаг хугацаа ордог; иймээс Бурханы үгийн улмаас хүмүүс цэвэршүүлэгддэг. Энэ нь бас зовлонгийн нэг хэсэг юм. Агуу улаан лууны газар нутагт Өөрийн ажлыг явуулах нь Бурханд асар хэцүү байдаг боловч ийм бэрхшээлээр дамжуулан Бурхан Өөрийн ажлын нэг үе шатыг хэрэгжүүлж, Өөрийн мэргэн ухаан, гайхалтай үйл хэргийг харуулдгийн дээр энэ бүлэг хүнийг бүрэн төгс болгохын тулд энэхүү боломжийг ашигладаг. Хүмүүсийн амссан зовлон, тэдний хэв чанар болон энэ бузар газар нутаг дахь хүмүүсийн бүх сатанлаг зан чанарын улмаас Бурхан ариусгалт, байлдан дагуулалтын ажлаа явуулдаг, ингэснээр Тэр үүнээс алдар сууг олж, Өөрийнх нь үйл хэргийг гэрчилдэг хүмүүсийг олж авч болох юм. Энэ бүлэг хүмүүсийн төлөө Бурханы гаргасан бүх золиосны утга учир бүхэлдээ ийм билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийг нь эсэргүүцдэг хүмүүсээр л дамжуулан байлдан дагуулах ажлыг хийдэг. Ингэж байж л Бурханы агуу хүч чадлыг харуулж чадна. Өөрөөр хэлбэл, бохир газар нутагт байгаа хүмүүс л Бурханы алдрыг өвлөн авбал зохих бөгөөд энэ л Бурханы агуу хүч чадлыг тодотгож чадна. Иймээс бохир заваан газар нутгаас, бохир заваан газар амьдардаг хүмүүсээс Бурханы алдрыг олж авдаг. Бурханы хүсэл ийм билээ. Есүсийн ажлын үе шат үүнтэй ижил байсан: Тэрээр Өөрийг нь хяхан хавчсан фарисайчуудын дунд л алдрыг олж авч чадах байсан. Фарисайчууд хяхан хавчиж, Иудас урваагүй бол Есүс цовдлуулах нь бүү хэл доог тохуу болж, гүжирдүүлэхгүй,

ингэснээрээ алдрыг олж авч чадахгүй байх байсан. Бурхан эрин үе болгонд, махбодод ажлаа хийхдээ алдрыг олж авч, олж авахаар зорьсон хүмүүсээ олж авдаг. Энэ бол Бурханы ажлын төлөвлөгөө, Түүний удирдлага билээ.

Хэдэн мянган жилийн Бурханы төлөвлөгөөнд хоёр хэсэг ажлыг махбодоор хийдэг: Эхнийх нь цовдлогдох ажил, үүгээр Тэр алдрыг олж авдаг; нөгөө нь эцсийн өдрүүд дэх байлдан дагуулж, төгс болгох ажил, үүгээр Тэр алдрыг олж авдаг. Энэ бол Бурханы удирдлага юм. Тиймээс Бурханы ажил болоод Бурханы та нарт өгсөн даалгаврыг энгийн зүйл гэж бүү бод. Та нар бүгдээрээ Бурханы үлэмж арвин, мөнхийн алдрын өв залгамжлагчид бөгөөд үүнийг Бурхан онцгойлон зарлигдсан. Түүний алдрын хоёр хэсгээс нэг нь та нарт илэрдэг; Бурханы алдрын нэг хэсгийг бүхэлд нь та нарт хайрласан агаад энэ нь та нарын өв байж болох юм. Бурхан та нарыг ийнхүү өргөмжилдгийн дээр энэ нь бас аль эртнээс урьдаас шийдсэн Түүний төлөвлөгөө билээ. Агуу улаан луу байдаг нутагт Бурханы хийсэн ажлын агуу байдлыг харгалзан үзвэл, тийм ажлыг хэрвээ өөр хаа нэг газар хийсэн бол аль хэдийн асар их үр дүнд хүрч, хүн амархан хүлээн зөвшөөрөх байсан. Бурханд итгэдэг Барууны санваартнуудын хувьд ийм ажлыг хүлээн зөвшөөрөх хэтэрхий амархан байх байсан, учир нь Есүсийн ажлын үе шат урьдын жишээ болдог. Ийм учраас өөр хаа нэгтээ байсан бол Бурхан алдар суу олж авах ажлын энэ үе шатанд хүрч чадахгүй; ажлыг хүмүүс дэмжиж, улс үндэстнүүд хүлээн зөвшөөрөх үед Бурханы алдар суу амжилттай болж чадахгүй. Энэхүү газар нутагт ажлын энэ үе шатыг хэрэгжүүлсний хосгүй ач холбогдол нь яг энэ юм. Та нарын дунд хуулиар хамгаалагддаг нэг ч хүн байхгүй; харин ч та нар хуулиар хориглуулдаг. Хүмүүс та нарыг ойлгодоггүй нь бүр ч илүү асуудалтай: Хамаатан садан, эцэг эх, найзууд, хамтран ажиллагсдын хэн нь ч та нарыг ойлгодоггүй. Бурхан та нарыг хаях үед газар дэлхий дээр үргэлжлүүлэн амьдрах ямар ч аргагүй болсон байлаа ч гэсэн хүмүүс Бурханыг орхиж явж тэвчдэггүй; энэ бол Бурхан хүмүүсийг байлдан дагуулахын ач холбогдол, мөн Бурханы алдар билээ. Өнөөдөр та нарын өвлөж авсан зүйл эрин үеүдийн туршид байсан элч, эш үзүүлэгч нарынхаас хавьгүй илүү, бүр Мосе, Петр хоёрынхоос ч үлэмж их юм. Ерөөлийг ганц, хоёрхон өдөрт хүртэж чадахгүй; асар ихийг золиосолж байж олж авах ёстой. Өөрөөр хэлбэл, цэвэршүүлэлтийг туулсан хайр, асар их итгэл, Бурхан та нараас хүрэхийг шаарддаг олон үнэн та нарт байх ёстой; дээр нь та нар бэргэж, зугталгүй шударга ёсыг сонгож, Бурханыг үхэх хүртлээ тууштай хайрлах ёстой. Та нар шийдэмгий байж, амь зан чанараа өөрчилж, завхралаа эдгээж, Бурханы зохион байгуулалтыг бүгдийг нь ямар ч гомдолгүйгээр хүлээн авч, бүр үхэх хүртлээ дуулгавартай байх ёстой. Та нарын үүнд хүрэх учиртай. Энэ бол Бурханы ажлын эцсийн зорилт, мөн энэхүү бүлэг хүмүүсээс Бурханы шаарддаг зүйл билээ. Тэр та нарт өгдөг болохоор хариуд нь та нараас шаардах нь гарцаагүй, зүй ёсны шаардлага тавих нь дамжиггүй. Тиймээс Бурханы бүх ажилд учир шалтгаан байдаг бөгөөд өндөр стандарт, хатуу чанд шаардлага тогтоосон ажлыг Бурхан яагаад ахин дахин

хийдгийг үүнээс харж болно. Ийм учраас та нар Бурханд итгэх итгэлээр дүүрэх учиртай. Товчхондоо Өөрийнх нь өвийг хүлээж авбал зохих хүмүүс болоосой гэсэндээ Бурхан бүх ажлаа та нарын төлөө хийдэг. Бурхан Өөрийн алдрын төлөө биш та нарын авралын төлөө, бохир газарт гүнээ зовж шаналсан энэ бүлэг хүмүүсийг төгс болгохын төлөө үүнийг хийдэг билээ. Та нар Бурханы хүслийг ойлгох ёстой. Иймээс ямар ч мэдлэг ухаан, эрүүл ухаан байхгүй харанхуй бүдүүлэг олон хүнд Бурханыг бүү турш, эсэргүүцэхээ боль гэж Би захидаг. Хүний хэзээ ч туулаагүй зовлонг Бурхан аль хэдийн туулж, аль хэдийнээ хүний оронд илүү их доромжлол амссан. Өөр юуг та нар зүгээр орхиж чадахгүй вэ? Юу Бурханы хүслээс илүү чухал байж болох билээ? Юу Бурханы хайраас дээгүүр байж болох билээ? Энэхүү бохир газарт Өөрийн ажлыг хэрэгжүүлэх нь Бурханд хангалттай хэцүү байгаа; дээр нь нэмээд хүн мэдсээр байж санаатайгаар гэм бурууг үйлдвэл Бурханы ажил сунжрах ёстой болно. Товчоор хэлбэл энэ нь хэнд ч ашиггүй, хэнд ч тусгүй. Бурхан цаг хугацаанд баригддаггүй; Түүний ажил болоод алдар суу нэгдүгээрт байдаг. Тиймээс, хэчнээн удсан ч хамаагүй Өөрийн ажлын төлөө Тэр юугаа ч хайрлахгүй. Энэ бол Бурханы зан чанар: Ажлаа дуусгах хүртлээ Тэр санаа амрахгүй. Өөрийн алдрын хоёр дахь хэсгийг олж авсан цагт л ажил нь дуусна. Бурхан алдрыг олж авах ажлын хоёр дахь хэсгийг бүх орчлон ертөнцөд дуусгахгүй бол Түүний өдөр хэзээ ч ирэхгүй, Түүний гар сонгосон хүмүүсээ хэзээ ч орхихгүй, Түүний алдар Израильд хэзээ ч ирэхгүй, мөн төлөвлөгөө нь хэзээ ч гүйцэлдэхгүй. Та нар Бурханы хүслийг харж чаддаг, Бурханы ажил нь тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээхтэй адил энгийн биш гэдгийг харах ёстой. Яагаад гэвэл, өнөөдрийн ажил нь завхарсан, хөшүүн болсон хүмүүсийг дээд зэргээр өөрчилж, бүтээгдсэн мөртөө Сатанаар боловсруулагдсан хүмүүсийг ариусгах явдал юм. Энэ нь Адам, Еваг бүтээх биш, тэр ч байтугай гэрлийг бий болгох, ургамал, амьтан бүрийг бүтээх ч биш. Сатаны завхруулсан зүйлсийг Бурхан ариун болгосныхоо дараа шинээр олж авдаг; тэдгээр нь Түүнд харьяалагддаг зүйл, Түүний алдар болдог. Энэ бол хүний төсөөлдөг шиг биш, тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн шиг эсвэл Сатаныг ёроолгүй нүх рүү хараах ажил шиг энгийн биш. Харин ч энэ нь хүнийг өөрчилж, сөрөг зүйлийг эерэг болгож, Өөрт нь харьяалагддаггүй зүйлийг Өөрийн болгох ажил билээ. Энэ бол Бурханы ажлын энэ үе шатны цаадах үнэн юм. Та нар үүнийг ойлгож, асуудлыг хэт энгийн болгохоос зайлсхийх ёстой. Бурханы ажил ямар ч энгийн ажилтай адилгүй. Үүний гайхалтай байдал, мэргэн ухааныг хүн ухаарч ойлгохын аргагүй билээ. Ажлын энэ үе шатанд Бурхан бүх зүйлийг бүтээдэггүй боловч бас устгадаг ч үгүй. Харин ч, Тэр бүтээсэн бүх зүйлээ өөрчилж, Сатаны бузарласан бүх зүйлийг ариусгадаг. Тиймээс Бурхан асар их хэмжээний ажлыг эхлүүлсэн нь Түүний ажлын утга учир тэр чигээрээ юм. Эдгээр үгээс чи Бурханы ажил үнэхээр тийм энгийн гэдгийг харж байна уу?

ЧИ БУРХАНД ИТГЭДЭГ ТУЛ ҮНЭНИЙ ТӨЛӨӨ АМЬДРАХ УЧИРТАЙ

Бүх хүнд байдаг нийтлэг асуудал бол үнэнийг ойлгодог хэр нь хэрэгжүүлж чаддаггүйд оршино. Энэ нь нэг талаар тэд төлөөс төлөхийг хүсдэггүй, нөгөө талаар тэдний ялган таних чадвар хэтэрхий хангалтгүй учраас тэр юм; тэд өдөр тутмын амьдрал дээрх олон бэрхшээлийн мөн чанарыг харж чаддаггүй, хэрхэн зүй зохистойгоор хэрэгжүүлэхээ мэддэггүй. Хүн хэтэрхий туршлага нимгэн, ядмаг хэв чанартай, үнэний талаар хязгаарлагдмал ойлголттой байдаг болохоор өдөр тутмын амьдралд тулгарах бэрхшээлийг шийдвэрлэх аргагүй байдаг. Тэд аман дээрээ л Бурханд итгэдэг болохоос Бурханыг өдөр тутмын амьдралдаа оруулах чадваргүй байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан бол Бурхан, амьдрал бол амьдрал бөгөөд Бурхан хүний амьдралд ямар ч хамаагүй мэт байдаг. Бүх хүн ингэж боддог. Хүмүүс Бурханд ингэж итгэснээрээ бодит байдал дээр Бурханаар авхуулж, төгс болгуулахгүй. Үнэндээ, Бурханы үг дутуу илэрхийлэгдсэн хэрэг биш, харин үгийг нь хүлээн авах хүмүүсийн чадвар л хэтэрхий хангалтгүй байгаа юм. Бараг хэн ч Бурханы анхны санаа зорилгын дагуу үйлддэггүй гэж хэлж болно. Харин ч тэд өөрсдийн санаа зорилго, өмнө нь баримталж байсан шашны үзэл, юмыг хийх арга барилынхаа дагуу Бурханд итгэдэг. Тун цөөн хүн Бурханы үгийг хүлээн зөвшөөрснийхөө дараа өөрчлөгдөж, Бурханы хүслийн дагуу үйлдэж эхэлдэг. Харин тэд буруу итгэлээ хадгалсаар байдаг. Хүн Бурханд итгэж эхлэхдээ шашны хэвшмэл дүрэмд тулгуурлан итгэдгийн дээр амьдралын талаарх гүн ухаан дээрээ л үндэслэн аж төрж, бусадтай харилцдаг. Арван хүн тутмын ес нь иймэрхүү байдаг гэж хэлж болно. Тун цөөхөн хүн л Бурханд итгэж эхэлснийхээ дараа өөр төлөвлөгөө боловсруулж, шинэ амьдрал эхэлдэг. Хүн төрөлхтөн Бурханы үгийг үнэн гэж боддоггүй, үнэн гэж үзэж, хэрэгжүүлдэггүй.

Жишээлбэл Есүст итгэх итгэлийг аваад үзье. Хүн дөнгөж итгэж эхэлсэн ч бай, эсвэл удаан хугацаанд итгэсэн ч бай, бүгд ердөө л өөрт нь ямар “авьяас” байна түүнийгээ ашиглаж, ямар “ур чадвар” эзэмшсэн түүнийгээ харуулсан. Хүмүүс ердөө л “Бурханд итгэх итгэл” гэсэн гурван үгийг ердийн амьдралдаа нэмсэн болохоос зан чанартаа ямар ч өөрчлөлт гаргаагүй бөгөөд Бурханд итгэх итгэл нь өчүүхэн төдий ч өсөөгүй. Тэдний эрэл хайгуул үлбэгэр байв. Тэд итгэхээ болино гэж хэлээгүй боловч бас Бурханд бүхнээ зориулаагүй. Хэзээ ч Бурханыг үнэн голоосоо хайрлаж, дуулгавартай дагаж байгаагүй. Бурханд итгэх итгэл нь үнэн худал хоёрын холимог, нэг нүдээ нээж, нөгөө нүдээ аньж хандсан бөгөөд итгэлээ хэрэгжүүлэхдээ үнэн сэтгэлээсээ хандаагүй. Тэд ийм төөрөлдсөн байдлаар үргэлжлүүлсээр эцэст нь самуурч үхсэн. Энэ бүхэн ямар учиртай вэ? Өнөөдөр чи бодитой Бурханд итгэхийн тулд зөв замд хөл тавих ёстой. Чи Бурханд итгэдэг бол зөвхөн ерөөл эрж хайх биш, харин Бурханыг хайрлаж, Бурханыг мэдэхээр эрж хайх ёстой. Чи Түүний гэгээрэл болоод өөрийнхөө эрлээр дамжуулан Түүний үгийг идэж, ууж, Бурханы

талаар жинхэнэ ойлголттой болж, зүрх сэтгэлийнхээ гүнээс Бурханыг жинхэнээсээ хайрладаг болж чадна. Өөрөөр хэлбэл, Бурханыг гэсэн хайр чинь хэн ч сүйтгэж, саад болж чадахааргүй хамгийн жинхэнэ байх үед чи Бурханд итгэх зөв замаар явж байдаг. Чамайг Бурханд харьяалагддагийг энэ нь батална, учир нь зүрх сэтгэл чинь аль хэдийн Бурханы өмч болж өөр юу ч чамайг эрхшээлдээ оруулж чадахгүй. Өөрийн туршлага, төлсөн төлөөс болон Бурханы ажлын улмаас чи Бурханыг өөрийн эрхгүй хайрлаж чаддаг. Тэр үед чи Сатаны нөлөөнөөс ангижирч, Бурханы үгийн гэрэлд ирж амьдарна. Чи харанхуйн нөлөөнөөс ангижирсан үедээ л Бурханыг олж авсан гэж хэлж чадна. Бурханд итгэхдээ чи энэ зорилгыг эрж хайхыг хичээх ёстой. Энэ бол та нарын хүн нэг бүрийн үүрэг билээ. Та нараас хэн нь ч хэрэг явдлын одоогийн байгаа байдалд сэтгэл хангалуун байх ёсгүй. Та нар Бурханы ажилд хоёрдмол сэтгэлээр, хөнгөн хуумгай хандаж болохгүй. Та нар Бурханыг бүхий л талаар, цаг үргэлжид бодож, бүх зүйлийг Түүний төлөө хийх ёстой. Та нар ярих юм уу үйлдэх болгондоо Бурханы гэрийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих хэрэгтэй. Зөвхөн ингэснээр л Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадна.

Хүмүүсийн Бурханд итгэхдээ гаргадаг хамгийн том алдаа нь тэд аман дээрээ л итгэдэг бөгөөд өдөр тутмын амьдралд нь Бурхан огт байдаггүй. Бүх хүн Бурханы оршихуйд үнэхээр итгэдэг хэр нь Бурхан өдөр тутмын амьдралынх нь нэг хэсэг биш байдаг. Бурханд хандсан олон залбирал хүмүүсийн амнаас гардаг боловч зүрх сэтгэлд нь Бурхан маш бага зай эзэлдэг учраас Бурхан тэднийг ахин дахин шалгадаг. Хүн цэвэр ариун биш болохоор хүмүүсийг шалгахаас өөр сонголт Бурханд байдаггүй, ингэснээр шалгалтын дунд тэд ичгүүрийг мэдэрч, өөрсдийгөө мэдэж авч болох юм. Эс бөгөөс хүн төрөлхтөн тэргүүн тэнгэр элчийн үр удам болж, улам бүр завхардаг. Хүн бүр Бурханд итгэх явцдаа Бурханаар тасралтгүй цэвэрлэгддэг учраас хувийн олон сэдэл, зорилгоо хөсөр хаядаг. Эс бөгөөс, Бурхан хэнийг ч ашиглах аргагүй, хийх ёстой ажлаа хүнд хийх ямар ч аргагүй болно. Бурхан эхлээд хүмүүсийг цэвэрлэдэг. Ийнхүү цэвэрлэх явцад хүмүүс өөрсдийгөө мэдэж авч, Бурхан тэднийг өөрчилж болох юм. Үүний дараа л Бурхан Өөрийн амийг тэдэн рүү оруулдаг бөгөөд ингэж байж л зүрх сэтгэл нь Бурхан руу бүрэн эргэж чадна. Тиймээс Бурханд итгэх нь хүмүүсийн хэлдэг шиг энгийн зүйл биш гэж Би хэлдэг. Бурханы харж байгаагаар чи зөвхөн мэдлэгтэй атлаа Түүний үгийг амиа болгоогүй бол; чи зөвхөн мэдлэгээр хязгаарлагдаад, үнэнийг хэрэгжүүлж, Бурханы үгийг амьдран харуулж чаддаггүй бол, энэ нь чамд одоог хүртэл Бурханыг хайрлах зүрх сэтгэл байхгүй гэдгийн баталгаа бөгөөд зүрх сэтгэл чинь Бурханд харьяалагддаггүй гэдгийг харуулдаг. Бурханд итгэснээрээ хүн Түүнийг мэдэж авч чадна: Энэ бол хүний эрж хайх учиртай эцсийн зорилго юм. Бурханы үгийг өөрийн биеэр хэрэгжүүлэхийн тулд чи тэдгээрийг амьдран харуулахад хүчин чармайлт гаргах ёстой. Хэрвээ чи зөвхөн хоосон сургаалын талаар мэддэг бол Бурханд итгээд ямар ч үр дүнгүй. Түүний үгийг бас хэрэгжүүлж, амьдран харуулж байгаа цагт л итгэл чинь бүрэн дүүрэн агаад Бурханы хүсэлд нийцэж байна гэж үзэх

боломжтой. Энэ зам дээр их мэдлэгийн талаар олон хүн ярьж чадах хэдий ч үхэх цаг нь ирэхэд нүдэнд нь нулимс цийлгэнэн, нэг насны амьдралаа дэмий үрж, насан өндөр болтлоо хий дэмий амьдарсандаа өөрсдийгөө үзэн яддаг. Тэд сургаалыг л ойлгодог болохоос үнэнийг хэрэгжүүлж, Бурханд гэрчлэл хийж чаддаггүй; харин гагцхүү бүхий л амьдралаа хаа сайгүй гүйж, зөгий шиг завгүй өнгөрүүлдэг; үхлийн ирмэгт ирэхдээ л өөрт нь жинхэнэ гэрчлэл байхгүй, Бурханыг огт мэддэггүй гэдгээ олж хардаг. Тэр үед хэтэрхий хожимдсон байх бус уу? Яагаад чи өнөөдрийг ашиглан, өөрийн хайрладаг үнэнийг эрж хайж болохгүй гэж? Яагаад маргааш хүртэл хүлээх гэж? Амьдралдаа чи үнэний төлөө зовдоггүй, үүнийг олж авахаар эрж хайдаггүй бол үхэх мөчдөө харууслыг мэдэрмээр байгаа хэрэг үү? Хэрэв тийм бол яагаад Бурханд итгэнэ вэ? Үнэндээ, хүмүүс өчүүхэн төдий л чармайлт гаргавал үнэнийг хэрэгжүүлж, ингэснээрээ Бурханыг сэтгэл хангалуун болгож чадах олон хэрэг явдал бий. Хүмүүсийн зүрх сэтгэлийг чөтгөрүүд байнга эзэмддэг учраас л тэд Бурханы төлөө үйлдэж чадахгүй, махан биеийн төлөө байнга нааш цааш гүйсээр, эцэстээ юунд ч хүрдэггүй. Ийм учраас хүмүүс байнга төвөг, бэрхшээлд шаналж байдаг. Сатаны тамлалт энэ бус уу? Махан биеийн ялзрал энэ бус уу? Чи аман дээрээ дагасан болж Бурханыг хуурах гэж оролдох хэрэггүй. Харин бодитой үйлдэл хийх хэрэгтэй. Өөрийгөө бүү хуур; тэгэх ямар хэрэг байна? Махан биеийнхээ төлөө амьдарч, нэр алдар, ашиг хонжооны төлөө тэмцсэнээр чи юу олж авч чадах юм бэ?

ДОЛООН АЯНГЫН НҮРГЭЭН— ХААНЧЛАЛЫН САЙН МЭДЭЭ ЕРТӨНЦ ДАЯАР ТАРХАХЫГ ЗӨГНӨЖ БАЙНА

Би өөрийн ажлыг Харь үндэстнүүдийн дунд түгээж байна. Миний алдар суу ертөнц даяар гялалздаг; од-од-цэг-цэг хүмүүс бүгд Миний хүслийг дотроо тээж, бүгд Миний гараар залуурдуулж, Миний даалгасан даалгаврыг эхлүүлэхээр бэлддэг. Энэ мөчөөс эхлэн би шинэ эрин үе рүү орж, бүх хүнийг өөр ертөнцөд авчирлаа. Би “эх нутаг” руугаа буцахдаа анхны төлөвлөгөөнийхөө өөр нэгэн хэсгийг эхлүүлсэн, ингэснээр хүн Намайг илүү гүнзгий мэддэг болно. Би хорвоо ертөнцийг бүхэлд нь хардаг бөгөөд энэ цаг үеийг миний ажилд тохиромжтой гэж үзэж байна.[a] Тиймээс Би хаа сайгүй яаравчлан, хүн дээр шинэ ажлаа гүйцэтгэж байна. Эцсийн эцэст энэ бол шинэ эрин үе бөгөөд Би илүү олон шинэ хүнийг шинэ эрин үе рүү оруулах, хаях ёстой хүмүүсээсээ илүү олныг таягдан хаяхын тулд шинэ ажлыг авчирлаа. Агуу улаан лууны улсад Би хүн төрөлхтний ойлгошгүй ажлын үе шатыг хэрэгжүүлсэн бөгөөд үүний улмаас хүн төрөлхтөн салхинд ганхаж, дараагаар нь олонх нь үлээх салхинд туугдан чимээгүй одсон. Чухамдаа, энэ бол Миний

[a] Эх бичвэрт “гэж үзэж байна” гэх хэллэг байдаггүй.

цэвэрлэх гэж буй “шигшүүрийн талбай”; энэ бол Миний хүсэж буй зүйл бөгөөд Миний төлөвлөгөө юм. Намайг ажлаа гүйцэтгэж байхад олон хорон санаатан шургалан орж ирсэн ч Би тэднийг хөөх гэж яарахгүй байна. Харин цаг нь болоход Би тэднийг тараан сарниулна. Түүний дараа л Би амийн ундарга болж, Намайг үнэхээр хайрладаг хүмүүст Надаас инжир модны үр жимс, сараана цэцгийн үнэрийг авах боломж олгоно. Сатан оршин суудаг, тоос шороотой газарт шижир алт үлдээгүй, элс л байдаг тул эдгээр нөхцөл байдалтай тулгараад Би ажлын ийм үе шатыг хийдэг. Миний эндээс олж авах зүйл бол элс биш шижир, тунгаамал алт гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Хорон санаатнууд Миний гэрт яахан үлдэж болох билээ? Миний диваажинд үнэг шимэгч болохыг Би яахан зөвшөөрөх билээ? Эднийг зайлуулахын тулд Би ашиглаж болох бүх аргыг ашиглана. Миний хүсэл илчлэгдэхээс өмнө хэн ч Миний юу хийх гэж буйг мэддэггүй. Энэ завшааныг ашиглан Би тэдгээр хорон санаатныг хөөж, тэд Миний дэргэдээс холдохоос өөр аргагүй болно. Хорон санаатнуудад Би ийм зүйл хийдэг ч Надад үйлчлэл хийх өдөр тэдэнд бас ирнэ. Хүмүүсийн адислал хүртэх хүсэл хэтэрхий хүчтэй байна; тиймээс Би эргэн харж, Харь үндэстнүүдэд алдар суут төрхөө харуулах болно. Ингэснээр хүмүүс бүгд өөрсдийн ертөнцөд амьдарч, өөрсдийгөө шүүх хооронд Би хэлэх ёстой үгээ хэлж, хүмүүсийг хэрэгтэй зүйлээр нь хангасаар байна. Хүн төрөлхтөн ухаан ороход Би ажлаа аль эрт түгээчихсэн байх болно. Дараа нь Би хүмүүст хүслээ илэрхийлж, ажлынхаа хоёр дахь хэсгийг хүмүүс дээр эхлүүлж, ажилтай минь зохицохын тулд Намайг ойрхон дагахыг бүх хүнд зөвшөөрч, хийх ёстой ажлыг минь хамт хийлцэхийн тулд чадах бүхнээ хийх боломжийг хүнд олгоно.

Миний алдар сууг харна гэж хэн ч итгэдэггүй бөгөөд Би ч тэднийг албаддаггүй, харин хүн төрөлхтний дундаас алдар суугаа салган авч, өөр ертөнцөд аваачдаг. Харин хүмүүс дахин гэмшихэд Би алдар суугаа авч ирэн, итгэл үнэмшилтэй илүү олон хүнд үзүүлэх болно. Энэ бол Миний ажилладаг зарчим. Миний алдар суу Канааныг орхих цаг байдгийн адил Миний алдар суу сонгогдсон хүмүүсийг орхих үе бас бий. Цаашилбал Миний алдар суу бүх дэлхийг орхин, дэлхий ертөнц бүүдийж, харанхуй руу умбах цаг үе бий. Канааны нутаг хүртэл нарны гэрлийг харахгүй; бүх хүн итгэлээ алдах болно, гэхдээ Канаан нутгийн анхилам үнэрийг хэн ч орхиж түвдэхгүй. Шинэ тэнгэр газар руу орохдоо л Би алдар сууныхаа нөгөө хэсгийг авч ирэн, Канааны нутагт анхлан дэлгэж, улмаар шөнийн тас харанхуйд живсэн дэлхий даяар сүүмэлзэх гэрэл гаргана, ингэснээр бүх дэлхий гэрэлд гарна; газар дэлхийн өнцөг булан бүрд байгаа хүмүүс гэрлийн хүчнээс хүч чадал авахаар ирж, алдар сууг минь улам бүр нэмэгдүүлэн, улс орон бүрд шинээр гарч ирэх боломж олгоно; Намайг хүний ертөнцөд аль эрт ирж, алдар суугаа аль эрт Израилиас зүүн зүгт аваачсаныг бүх хүн төрөлхтөн ухаарна; учир нь Миний алдар суу Зүүн зүгээс гэрэлтдэг бөгөөд үүнийг Нигүүлслийн эрин үеэс энэ өдөрт авчирсан. Гэхдээ Израиль бол Миний орхиж гарсан нутаг бөгөөд тэндээс би зүүн зүгт ирсэн. Зүүн зүгийн гэрэл аажмаар цайрах үед л дэлхий даяарх харанхуй

аажмаар гэгээрч эхлэх ба тэр үед л Намайг Израилиас аль хэдийн яваад зүүн зүгт шинээр мандаж буйг хүн олж мэднэ. Нэгэн цагт Би Израильд бууж, дараа нь тэндээс явсан учир Израильд дахин төрж чадахгүй. Учир нь Миний ажил бүх орчлон ертөнцийг удирдан чиглүүлдэг бөгөөд үүнээс гадна аянга шууд зүүнээс Баруун зүгт цахидаг. Энэ шалтгааны улмаас Би зүүн зүгт бууж, Канааныг зүүн зүгийн хүмүүст авчирсан. Би хүмүүсийг дэлхийн өнцөг булан бүрээс Канааны нутагт авчирна, тиймээс бүх ертөнцийг удирдахын тулд Канааны нутагт айлдвараа айлдсаар байх болно. Одоо Канаанаас бусад бүх газарт гэрэл байхгүй бөгөөд бүх хүн өлсгөлөн, хүйтний аюулд нэрвэгдээд байна. Би алдар суугаа Израильд өгч, дараа нь буцаан авсан, улмаар израильчуудыг болон бүх хүн төрөлхтнийг зүүн зүгт аваачсан. Би бүгдийг нь гэрэлд авчирсан, ингэснээр тэд дахин гэрэлтэй золгож, холбоотой болж, цаашид гэрлийг хайх шаардлагагүй болно. Гэрлийг хайж буй бүх хүнд гэрлийг дахин харуулж, Израильд байсан алдар суугаа Би харуулна; Би аль эрт хүн төрөлхтний дунд цагаан үүл хөлөглөн бууж ирснийг, тоолж баршгүй цагаан үүл, элбэг дэлбэг жимсийг багц багцаар нь тэдэнд харуулж, цаашлаад Израилийн Ехова Бурханыг харуулна. Би тэдэнд иудейчүүдийн Эзэн, удаан хүлээсэн Мессиаг болон үеийн үед хаадад хавчигдан шахагдаж ирсэн Өөрийнхөө дүр төрхийг бүтнээр нь харуулна. Би орчлон ертөнц даяар ажиллаж, агуу ажил гүйцэтгэн, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд бүхий л алдар суу, үйлээ илчилнэ. Би олон жил Намайг хүлээж байсан хүмүүст, Намайг цагаан үүл хөлөглөн ирэхийг хүсэн хүлээсэн хүмүүст, дахин нэг удаа гарч ирэхийг минь хүсэн хүлээж байсан Израильд болон Намайг хавчин шахдаг бүхий л хүн төрөлхтөнд өөрийн алдар суут төрхөө бүрэн дүүрэн харуулна. Ингэснээр Би аль эрт алдар суугаа аваад, зүүн зүгт авчирсан, Миний алдар суу Иудейн нутагт байхаа больсон гэдгийг бүгд мэдэх болно. Учир нь эцсийн өдрүүд аль хэдийн ирсэн!

Орчлон даяар Би Өөрийн ажлыг хийж байна, зүүн зүгт аянга цахилгаан зогсолтгүй цахилж, бүх улс, шашны урсгалыг доргиодог. Миний дуу хоолой бүх хүнийг өнөөдөр лүү хөтөлсөн. Би бүх хүнийг дуу хоолойгоороо байлдан дагуулж, энэ урсгалд оруулж, Өөрийнхөө өмнө дуулгавартай байлгадаг, учир нь Би аль эрт Өөрийн алдар сууг бүх дэлхийгээс эгүүлэн татаж, зүүн зүгт шинээр гаргасан. Миний алдар сууг харахыг хүсэн хүлээдэггүй хэн байна вэ? Намайг эргэн ирэхийг сэтгэл түгшин хүлээдэггүй хэн байна вэ? Миний дахин илрэлтээр цангахгүй хэн байна вэ? Миний хайр татам байдлыг санагалзахгүй хэн байна вэ? Гэрэл рүү гарч ирэхгүй байх хэн байна вэ? Канааны баян тансаг руу хараа бэлчээхгүй хэн байх вэ? Золин аврагч эргэн ирэхийг хүсэн хүлээхгүй хэн байх вэ? Агуу эрх мэдэлтэй Түүнийг хүндлэн биширдэггүй хэн байна вэ? Миний дуу хоолой дэлхий даяар тархах болно; Би сонгосон хүмүүстэйгээ нүүр тулж, тэдэнд илүү олон үг хэлнэ. Уул, усыг доргиох хүчит аянга шиг бүх орчлон ертөнц, хүн төрөлхтөнд хандан Би үгээ хэлсэн. Тиймээс, Миний аман дахь үгс хүний эрдэнэ болж, хүмүүс бүгд Миний үгийг нандигнадаг. Аянга цахилгаан зүүнээс баруун зүг хүртэл цахилдаг. Миний үгс хүн

татгалзахааргүй байхын зэрэгцээ ойлгохын аргагүй боловч тэгэх тусмаа баярлан хөөрмөөр байдаг. Бүх хүн дөнгөж төрсөн нярай мэт Миний ирснийг тэмдэглэж, баяр хөөртэй байна. Дуу хоолойгоороо дамжуулан Би бүх хүнийг Өөрийнхөө өмнө авчрах болно. Түүнээс хойш Би албан ёсоор хүмүүсийн эгнээнд орох бөгөөд ингэснээр тэд Намайг шүтэн биширнэ. Цацруулж буй алдар суу, аман дахь үгээрээ Би бүх хүнийг өмнөө ирүүлэн, зүүн зүгээс аянга цахилж, зүүн зүгийн “Чидун жимсний уулан” дээр Өөрийгөө бууж ирснийг харуулна. Намайг иудейчүүдийн Хүүгийн хувьд биш, харин Зүүн зүгийн аянга болж газар дээр аль эртнээс байсныг тэд харах болно. Учир нь Би дахин амилж, хүн төрөлхтний дундаас холдон яваад удаж байгаа бөгөөд хүмүүсийн дунд алдар суутайгаар дахин гарч ирсэн. Би бол одоогоос тоолж баршгүй олон эрин үеийн өмнө шүтэгдэж байсан Тэр нэгэн, мөн Би одоогоос тоолж баршгүй олон эрин үеийн өмнө израильчуудын хаясан нярай билээ. Түүнээс гадна, Би энэ эрин үеийн хамгийн алдар суут Төгс Хүчит Бурхан билээ! Бүгд Миний сэнтийн өмнө ирж, Миний алдар суут төрхийг харж, дуу хоолойг минь сонсож, Миний үйлсийг харцгаа. Энэ бол Миний бүхий л хүсэл; Миний төлөвлөгөөний төгсгөл, оргил үе, мөн Миний удирдлагын зорилго: улс орон болгон Намайг шүтэн мөргөж, хэл болгон Намайг хүлээн зөвшөөрч, хүн бүр итгэлээ Надад өгч, бүх хүн Надад захирагдана!

БИЕ МАХБОДТОЙ БОЛСОН БУРХАН БОЛОН БУРХАНЫ АШИГЛАДАГ ХҮМҮҮСИЙН ХООРОНДОХ ҮНДСЭН ЯЛГАА

Олон жилийн турш Бурханы Сүнс газар дээр ажиллангаа тасралтгүй хайсаар ирсэн бөгөөд эрин үеүдийн туршид Өөрийн ажлыг хийхийн тулд Бурхан олон хүнийг ашиглажээ. Гэсэн ч энэ бүх хугацаанд Бурханы Сүнс тохиромжтой амрах газаргүй байсаар ирсэн учраас Бурхан ажлаа хийхийн тулд өөр өөр хүмүүсийн хоорондшилждэг. Ерөнхийдөө Түүний ажил хүмүүсээр дамжин хийгддэг. Өөрөөр хэлбэл, энэ бүх жилүүдэд Бурханы ажил хэзээ ч зогсоогүй, харин өнөөг хүртэл хүмүүсээр дамжин явагдсаар ирсэн юм. Бурхан маш олон үг хэлж, маш их ажил хийсэн хэдий ч Бурхан хүнд хэзээ ч харагдаж байгаагүй учраас, бас Түүнд бодит хэлбэр дүрс байдаггүй учраас хүн Бурханыг мөн л мэддэггүй. Иймээс Бурхан, бодитой Бурханы бодит ач холбогдлыг бүх хүнд мэдүүлэх энэхүү ажлыг гүйцэлдүүлэх ёстой. Энэ үр дүнд хүрэхийн тулд Бурхан Өөрийн Сүнсийг хүмүүст бодитоор илчилж, тэдний дунд ажлаа хийх ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс бие махбодын хэлбэртэй, мах цустай болж, хүмүүсийн дунд харагдахуйцаар алхаж, амьдралд нь тэднийг дагалдаж, Өөрийгөө заримдаа харуулж, заримдаа нуун далдалж байх үед л хүмүүс Түүний талаар илүү гүнзгий ойлголттой болж чадна. Хэрвээ Бурхан зөвхөн махбодод үлдсэн бол Өөрийн ажлыг бүхэлд нь

биелүүлж чадахгүй байх байв. Есүс хэсэг хугацаанд хэвийн хүн чанараар ажиллаж, гүйцэлдүүлэх хэрэгтэй байсан бүх ажлаа дуусгасны дараа явсантай яг адилаар Бурхан махбодод хэсэг хугацаанд ажиллаж, махбодоор хийх хэрэгтэй үйлчлэлийг гүйцэтгэснийхээ дараа махбодыг орхиж, махбодын дүрээр сүнсний ертөнцөд ажиллана. Та нар “Зам… 5”-ын энэ хэсгийг санаж байгаа байх: “Эцэг минь Надад ‘Газар дэлхий дээр Эцэгийнхээ хүслийг биелүүлж, Түүний даалгаврыг биелүүлэхийг л хичээ. Өөр юу ч Чамд хамаагүй’ гэж хэлснийг Би санадаг.” Чи энэ хэсгээс юу харж байна вэ? Бурхан газар дээр ирэх үедээ Өөрийнхөө ажлыг л бурханлаг чанараар хийдэг бөгөөд энэ бол бие махбодтой болсон Бурханд тэнгэрлэг Сүнсний даалгасан зүйл юм. Ирэх үедээ Тэр гагцхүү газар нутаг даяар үгээ хэлж, Өөрийн айлдваруудыг өөр өөр аргаар, өөр өөр өнцгөөс айлддаг. Тэр үндсэндээ хүнийг хангаж, хүнд зааж сургах явдлыг Өөрийн зорилго, ажиллах зарчим гэж авч үздэг бөгөөд хүн хоорондын харилцаа юм уу хүмүүсийн амьдралын нарийн ширийнийг анхаардаггүй. Түүний гол үйлчлэл нь Сүнсний өмнөөс ярих явдал юм. Өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс махбодод бодитоор илрэх үедээ зөвхөн хүний амийг хангаж, үнэнийг гаргадаг. Тэр хүний ажилд хутгалддаггүй, өөрөөр хэлбэл, хүмүүсийн ажилд оролцдоггүй. Хүмүүс бурханлаг ажил хийж чаддаггүй, Бурхан хүний ажилд оролцдоггүй. Бурхан Өөрийн ажлыг хийхээр энэ газар дэлхийд ирснээсээ хойш энэ бүх хугацаанд үүнийгээ үргэлж хүмүүсээр дамжуулан хийсэн юм. Гэхдээ энэ хүмүүсийг бие махбодтой болсон Бурхан гэж үзэж болохгүй, Бурханы ашигладаг хүмүүс л гэж үзэж болно. Харин өнөөдрийн Бурхан шууд бурханлаг чанарын өнцгөөс үг хэлж, Сүнсний дуу хоолойг илэрхийлж, Сүнсний өмнөөс ажиллаж чадна. Эрин үеүдийн туршид Бурханы ашигласан бүх хүн нь мөн л Бурханы Сүнс махан бие дотор ажилласан тохиолдол мөн—тэгвэл яагаад тэднийг Бурхан гэж нэрлэж болдоггүй юм бэ? Гэхдээ, өнөөдрийн Бурхан ч бас Бурханы сүнс шууд махбодоор ажиллаж буй хэрэг бөгөөд Есүс ч гэсэн махбодоор ажилласан Бурханы Сүнс байсан; энэ хоёрыг хоёуланг нь Бурхан гэж нэрлэдэг. Тэгвэл ялгаа нь юу вэ? Эрин үеүдийн туршид Бурханы ашигласан хүмүүс бүгд хэвийн бодолтой, эрүүл ухаантай байж чадсан. Тэд бүгд биеэ авч явах зарчмыг ойлгосон байв. Тэдэнд хэвийн хүний үзэл санаа байсан бөгөөд хэвийн хүмүүст байх ёстой бүх зүйлийг эзэмшсэн байлаа. Тэдний олонх нь ер бусын ур чадвартай, төрөлхийн ухаантай байсан юм. Энэ хүмүүс дээр ажиллахдаа Бурханы Сүнс, тэдэнд Бурханаас заясан билиг авьяас болох ур чадварыг нь ашигладаг. Бурханы Сүнс тэдний ур чадварыг нь ажиллуулж, Бурханы төлөө үйлчлэхэд давуу талыг нь ашигладаг. Гэсэн ч Бурханы мөн чанар нь үзэл санаа, бодлоос ангид, хүний далд санаа холилдоогүй байдаг ба хэвийн хүмүүсийн эзэмшдэг зүйл ч дутмаг байдаг. Өөрөөр хэлбэл, хүний биеэ авч явах зарчмыг ч Тэр сайн мэддэггүй. Өнөөдрийн Бурхан газар дээр ирэх үедээ ийм л байдаг. Түүний ажил болон үгэнд хүний санаа зорилго юм уу хүний бодол холилдоогүй байдаг, харин тэдгээр нь Сүнсний санаа зорилгын шууд илрэл бөгөөд Тэрээр Бурханы өмнөөс шууд ажилладаг. Энэ нь,

Сүнс шууд үг хэлдэг буюу хүний санаа зорилгыг өчүүхэн төдий ч холилгүйгээр бурханлаг чанар шууд ажил хийдэг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурхан бурханлаг чанарыг шууд агуулдаг, хүний бодол, үзэл санаанаас ангид байдаг бөгөөд хүний биеэ авч явах зарчмыг огт ойлгодоггүй. Хэрвээ зөвхөн бурханлаг чанар ажиллаж байсан бол (өөрөөр хэлбэл, зөвхөн Бурхан Өөрөө ажиллаж байсан бол) Бурханы ажлыг газар дээр гүйцэтгэх ямар ч аргагүй байх байлаа. Иймээс Бурханыг газар дээр ирэх үед, бурханлаг чанараар хийдэг ажлынхаа хамтаар хүн чанар дотор ажиллахдаа ашиглах цөөн тооны хүн Түүнд байх ёстой. Өөрөөр хэлбэл, бурханлаг чанарын ажлаа хадгалахын тулд Бурхан хүний ажлыг ашигладаг. Тэгэхгүй бол хүн бурханлаг ажилтай шууд холбогдох ямар ч аргагүй байх болно. Есүс болон Түүний шавь нарын хувьд ч ийм л байсан. Дэлхий дээр байх хугацаандаа Есүс хуучин хуулийг хүчингүй болгож, шинэ тушаалуудыг тогтоосон. Тэр бас олон үг хэлсэн юм. Энэ бүх ажил бурханлаг чанараар хийгджээ. Петр, Паул, Иохан гэх мэт бусад хүмүүс дараа нь Есүсийн үгэнд суурилан ажилласан билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан тухайн үед Өөрийн ажлыг эхлүүлж, Нигүүлслийн эрин үеийн эхлэлийг тавьсан буюу шинэ эрин үеийг авчран, хуучин эрин үеийг халсан бөгөөд бас “Бурхан бол Эхлэл ба Төгсгөл” хэмээх үгийг биелүүлсэн. Өөрөөр хэлбэл, хүн бурханлаг ажлын суурин дээр хүний ажлыг хийх ёстой. Есүс хэлэх хэрэгтэй бүхнээ хэлж, газар дээрх ажлаа дуусгамагцаа хүнийг орхиж одсон. Үүний дараа, ажиллаж байхдаа бүх хүн Түүний үгэнд илэрхийлэгдсэн зарчмын дагуу үйлдэж, Түүний хэлсэн үнэний дагуу хэрэгжүүлсэн юм. Энэ бүх хүн Есүсийн төлөө ажилласан. Хэрвээ Есүс ганцаараа ажил хийж байсан бол Тэр хэчнээн их үг хэлсэн ч бай, хүмүүс Түүний үгтэй холбогдох аргагүй байх байв, учир нь Тэр бурханлаг чанараар ажиллаж, бурханлаг чанарын үгийг л хэлж чадах байсан ба хэвийн хүмүүс үгийг нь ойлгож чадах хэмжээнд аливааг тайлбарлаж чадахгүй байх байлаа. Иймээс Түүний ажилд нэмэр болохоор араас нь ирсэн элчүүд болон эш үзүүлэгчид Түүнд хэрэгтэй байсан юм. Бурханлаг чанарын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд махбод болсон биеийг ашиглан үг хэлж, ажиллаад, дараа нь Өөрийн ажилд нэмэр болгохоор Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг цөөн хэдэн, эсвэл арай олон хүнийг ашиглах нь бие махбодтой болсон Бурханы ажилладаг зарчим билээ. Өөрөөр хэлбэл, Бурханы сонгосон хүмүүсийг үнэн-бодит байдалд оруулахын тулд Бурхан, хүмүүсийг хариулж, услах ажил хийлгэхээр Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүсийг ашигладаг.

Хэрвээ Бурхан махбодод ирэхдээ бурханлаг чанарын ажлыг л хийсэн ба зүрх сэтгэлийнх нь дагуу байдаг цөөн хэдэн хүн Түүнтэй хамтран ажиллаагүй бол хүн Бурханы хүслийг ойлгож, эсвэл Бурхантай харилцаж чадахгүй байх байв. Энэ ажлыг гүйцэлдүүлж, чуулганууды харж хандаж, хариулж, мөн хүний сэтгэхүй, ууараг тархи төсөөлж чадах түвшинд хүрэхийн тулд Бурхан Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг хэвийн хүмүүсийг ашиглах ёстой. Өөрөөр хэлбэл, Бурхан бурханлаг чанар дотор хийж байгаа ажлаа “орчуулахын” тулд Өөрийнх нь зүрх сэтгэлийн

дагуу байдаг цөөн тооны хүмүүсийг ашигладаг, ингэснээр үүнийг тайлж—бурханлаг хэлийг хүний хэл болгон хөрвүүлж чадах бөгөөд хүмүүс үүнийг ухамсарлаж, ойлгож чадна. Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүс эцсийн эцэст тун цөөхөн байдаг ба хүний ухамсарлах чадвар сул байдаг учраас хэрвээ Бурхан ийнхүү хийгээгүй бол хэн ч Бурханы бурханлаг хэлийг ойлгож чадахгүй байх байлаа. Тийм учраас махбод болсон биеэр ажиллаж байх үедээ л Бурхан энэ аргыг сонгодог. Хүн Бурханы хэлийг ойлгодоггүй учраас хэрвээ зөвхөн бурханлаг ажил л байсан бол хүний хувьд Бурханыг мэдэж, Түүнтэй холбогдох ямар ч аргагүй байх байв. Гагцхүү Түүний үгийг ойлгомжтой болгодог, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүсийн дэмжлэгтэйгээр л хүн энэ хэлийг ойлгож чадна. Гэхдээ, хүн чанар дотор ажилладаг тийм хүмүүс л байсан бол тэр нь хүний хэвийн амьдралыг хадгалж л чадах байлаа; энэ нь хүний зан чанарыг өөрчилж чадахгүй байх байв. Тэгвэл Бурханы ажил шинэ эхлэлийн цэгтэй байж чадахгүй; нэгэн хэвийн хуучин зүйлс, нэгэн хэвийн улиг болсон үгс л байх байсан юм. Бие махбодтой байх хугацаандаа хэлэх хэрэгтэй бүхнийг хэлж, хийх хэрэгтэй бүхнийг хийдэг бие махбодтой болсон Бурханы тусламжтайгаар л, мөн дараа нь хүмүүс Түүний үгийн дагуу ажиллаж, туулснаар л хүмүүсийн амь зан чанар өөрчлөгдөж чадах ба тэгж байж л тэд цаг хугацааны урсгалыг дагаж чадна. Бурханлаг чанар дотор ажилладаг Нэгэн нь Бурханыг төлөөлдөг, харин хүн чанар дотор ажилладаг хүмүүс Бурханаар ашиглагддаг. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурхан нь Бурханы ашигладаг хүмүүсээс мөн чанартаа өөр юм. Бие махбодтой болсон Бурхан бурханлаг чанарын ажлыг хийж чаддаг байхад Бурханы ашигладаг хүмүүс тэгж чаддаггүй. Эрин үе болгоны эхэнд, хүнийг шинэ эхлэл рүү аваачихын тулд Бурханы Сүнс биечлэн үг хэлж, шинэ эринийг эхлүүлдэг. Түүнийг үг хэлж дуусах үед, бурханлаг чанар доторх Бурханы ажил дууссан гэдгийг энэ нь илтгэдэг. Үүний дараа, амийн туршлага руу орохын тулд хүмүүс бүгд Бурханы ашигладаг хүмүүсийн удирдлагыг дагадаг. Тэрчлэн энэ нь бас Бурхан хүнийг шинэ эрин рүү аваачиж, хүмүүст шинэ эхлэлийн цэг өгдөг үе шат юм—энэ үед махбод дахь Бурханы ажил дуусдаг.

Бурхан хэвийн хүн чанараа төгс болгохын тулд газар дэлхий дээр ирдэггүй, хэвийн хүн чанарын ажлыг хийхийн тулд ч ирдэггүй. Гагцхүү хэвийн хүн чанараар бурханлаг ажил хийхийн тулд л ирдэг. Хэвийн хүн чанарын талаар Бурханы ярьдаг зүйл хүмүүсийн төсөөлдөгтэй адилгүй. Хүн “хэвийн хүн чанарыг” эхнэр, нөхөр, хөвгүүд, охидтой байх явдал гэж тодорхойлдог ба эдгээр нь тухайн хүн хэвийн хүн мөн гэдгийн нотолгоо юм; харин Бурхан ингэж үздэггүй. Тэрээр хэвийн хүн чанарыг, хэвийн хүний бодолтой, хэвийн хүний амьдралтай байж, хэвийн хүмүүсээс төрөх явдал гэж үздэг. Гэхдээ Түүний хэвийн байдал нь, хүн хэвийн байдлын талаар ярьдаг шиг эхнэр, нөхөр, үр хүүхэдтэй байхтай хамаагүй. Өөрөөр хэлбэл, Бурханы ярьдаг хэвийн хүн чанар нь, хүн чанаргүй, бараг сэтгэл хөдлөлгүй, хараажаар бие махбодын хэрэгцээгүй, яг л Есүстэй адил хэвийн хүний гадаад төрхтэй, хэвийн хүний дүртэй мөртөө мөн чанартаа хэвийн хүний эзэмших ёстой бүхнийг бүрэн

эзэмшээгүй гэж хүний үздэг зүйл юм. Үүнээс, бие махбодтой болсон Бурханы мөн чанар нь хэвийн хүн чанарыг бүхэлд нь агуулдаггүй, харин хэвийн хүний амьдралын хэвшлийг хангах, хэвийн хүний эрүүл ухааныг хадгалахын тулд хүмүүст байх ёстой зүйлийн нэг хэсгийг л агуулдаг гэдгийг харж болно. Гэхдээ эдгээр зүйл нь, хэвийн хүн чанар гэж хүний үздэг зүйлтэй ямар ч хамаагүй байдаг. Тэдгээр нь бие махбодтой болсон Бурханд байх ёстой зүйл юм. Гэсэн ч, бие махбодтой болсон Бурхан эхнэртэй, хөвгүүд охидтой, гэр бүлтэй л байх юм бол хэвийн хүн чанартай гэж хэлж болно хэмээн зүтгэдэг хүмүүс бий; эдгээр зүйл байхгүй бол Тэр хэвийн хүн биш гэж тэд хэлдэг. Тэгвэл Би та нараас ингэж асууя: “Бурханд эхнэр байдаг уу? Бурханы хувьд нөхөртэй байх боломжтой юу? Бурхан хүүхдүүдтэй байж болох уу?” Эдгээр нь төөрөгдөл биш гэж үү? Гэхдээ бие махбодтой болсон Бурхан хад чулууны хоорондох ан цаваас үсрэн гарах юм уу тэнгэрээс унаж ирж чадахгүй. Тэр гагцхүү хэвийн хүний гэр бүлд л төрж болно. Тийм учраас Түүнд эцэг эх, эгч дүүс байдаг. Эдгээр нь бие махбодтой болсон Бурханы хэвийн хүн чанарт байх ёстой зүйл юм. Есүсийн хувьд ч тийм байсан; Есүст эцэг эх, ах эгч дүүс байсан ба энэ бүхэн нь хэвийн байлаа. Гэвч хэрвээ Тэрээр эхнэр, хөвгүүд, охидтой байсан бол тэр нь бие махбодтой болсон Бурханд байх ёстой гэж Бурханы төлөвлөсөн хэвийн хүн чанар биш байх байлаа. Хэрвээ тийм байсан бол Тэр бурханлаг чанарын өмнөөс ажиллаж чадахгүй байх байв. Түүнд эхнэр, хүүхэд байгаагүй ч хэвийн гэр бүлд хэвийн хүмүүсээс төрсөн учраас л Тэрээр бурханлаг чанарын ажлыг хийж чадсан билээ. Үүнийг цааш тодруулбал, Бурханы хэвийн хүн гэж үздэг зүйл нь хэвийн гэр бүлд төрсөн хүн юм. Зөвхөн тийм хүн л бурханлаг ажил хийхэд тохирно. Нөгөө талаар, хэрвээ хүн эхнэр, хүүхэдтэй, эсвэл нөхөртэй байсан бол бурханлаг ажил хийж чадахгүй, учир нь тэр хүн хүмүүсийн шаарддаг хэвийн хүн чанарыг л эзэмших боловч Бурханы шаарддаг хэвийн хүн чанарыг эзэмшихгүй байх байв. Бурханы боддог зүйл болон хүмүүсийн ойлгодог зүйл ихэнхдээ асар их ялгаатай, шал өөр байдаг. Бурханы ажлын энэ үе шатанд хүмүүсийн үзэлтэй зөрчилддөг, хүмүүсийн үзлээс асар их зөрдөг зүйл олон бий. Бурханы ажлын энэ үе шат нь бүхэлдээ бурханлаг чанар шууд ажиллаж, хүн чанар дэмжих үүрэг гүйцэтгэхээс бүрддэг гэж хэлж болно. Учир нь Бурхан Өөрийн ажлыг хүний гараар хийлгэхийн оронд Өөрөө хийхээр газар дэлхий дээр ирдэг ба Өөрийн ажлыг хийхийн тулд Тэр Өөрөө бие махбодтой (бүрэн бус, хэвийн хүн) болдог. Тэрээр хүн төрөлхтөнд шинэ эрин үеийг харуулж, Өөрийн ажлын дараагийн алхмын талаар хүн төрөлхтөнд хэлэхийн тулд энэ бие махбодыг ашигладаг бөгөөд Өөрийнх нь үгэнд дүрсэлсэн замын дагуу хэрэгжүүлэхийг хүмүүсээс шаарддаг. Ийнхүү махбод дахь Бурханы ажил дуусдаг; Тэрээр хүн төрөлхтнөөс хагацаж, хэвийн хүн чанартай махбодод оршин байхаа болиод, харин ч Өөрийн ажлын өөр нэг хэсгийг явуулахын тулд хүнээс холдон явах гэж байна. Дараа нь, Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүсийг ашиглан Тэрээр энэ бүлэг хүмүүсийн дунд газар дээрх ажлаа үргэлжлүүлдэг боловч тэдний хүн чанараар ажилладаг.

Бурханд өөр хийх ажил маш их байдаг учраас бие махбодтой болсон Бурхан хүнтэй хамт үүрд байж чадахгүй. Тэр махбодоор хязгаарлагдаж болохгүй; хэдийгээр Тэр тус ажлыг махбодын дүрээр хийдэг ч хийх ёстой ажлаа хийхийн тулд махбодыг тайлан хаях хэрэгтэй болдог. Бурхан газар дээр ирэх үедээ хэвийн хүний хүрэх учиртай хэлбэрт хүрэхээ хүлээж, дараа нь насан эцэслээд, хүн төрөлхтнийг орхидоггүй. Түүний махбод хэдэн настай байх нь хамаагүй, ажил нь дуусах үед Тэр хүнийг орхиж явдаг. Түүний хувьд нас гэх зүйл байдаггүй, Тэр хүний амьдралын хугацааны дагуу Өөрийн өдөр хоногийг тоолдоггүй; оронд нь Өөрийн ажлын алхмуудад нийцүүлэн махбод дахь амиа төгсгөдөг. Бурхан махбодод ирээд тодорхой үе шат хүртэл өсөж, насанд хүрч, хөгшрөөд, тэрхүү бие махбод нь насан эцэслэх үед л явах ёстой гэж боддог хүмүүс байж магадгүй. Энэ бол хүний төсөөлөл; Бурхан тэгж ажилладаггүй. Тэрээр хийх ёстой ажлаа хийхийн тулд л махбодод ирдэг бөгөөд хэвийн хүний бүх үйл ажиллагаа буюу эцэг эхээс төрж, өсөж, гэр бүл зохиож, ажил мэргэжилтэй болж, үр хүүхэд төрүүлж өсгөж, эсвэл амьдралын сайн мууг туулан хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд ирдэггүй. Бурхан газар дээр ирэх үед Бурханы Сүнс махбод өмсөж, махбодод ирж буй хэрэг боловч Бурхан хэвийн хүний амьдралаар амьдардаггүй. Тэрээр удирдлагын төлөвлөгөөнийхөө нэг хэсгийг биелүүлэхийн тулд л ирдэг. Үүний дараа Тэр хүн төрөлхтнийг орхин явна. Махбодод ирэх үедээ Бурханы Сүнс бие махбодын хэвийн хүн чанарыг төгс болгодоггүй. Харин ч Бурханы урьдчилан тодорхойлсон цагт бурханлаг чанар шууд ажилладаг. Тэгээд Өөрийн хийх хэрэгтэй бүхнийг хийж, Өөрийн үйлчлэлийг бүрэн биелүүлсний дараа энэ үе шатан дахь Бурханы Сүнсний ажил дуусдаг, энэ мөчид бие махбодынх нь амьдрах хугацаа дууссан эсэхээс үл хамааран бие махбодтой болсон Бурханы амь ч бас төгсдөг. Өөрөөр хэлбэл, бие махбод амьдралын ямар үе шатанд хүрэх нь, газар дээр хэр урт наслах нь бүгд Сүнсний ажлаар шийдэгддэг. Энэ нь хүний хэвийн хүн чанар гэж үздэг зүйлтэй ямар ч хамаагүй. Есүсийг жишээ болгон авч үзье. Тэрээр махбодод гучин гурван жил хагас амьдарсан. Хүний биеийн амьдралын хугацааны хувьд бол Тэр уг насандаа үхэх ёсгүй байсан ба явах ёсгүй байсан юм. Гэхдээ үүнийг Бурханы Сүнс огт анхааралагүй. Түүний ажил дууссан, тэр мөчид биеийг нь авч одож, бие нь Сүнстэй хамт алга болсон. Энэ нь Бурханы махбодод ажилладаг зарчим юм. Иймээс нарийн яривал, бие махбодтой болсон Бурханы хүн чанар гол чухал биш. Дахин хэлэхэд, Тэрээр хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд газар дээр ирдэггүй. Тэр эхлээд хэвийн хүний амьдралыг бүтээгээд дараа нь ажиллаж эхэлдэггүй. Харин ч хэвийн хүний гэр бүлд төрсөн л бол Тэрээр бурханлаг ажил буюу хүний санаа зорилго холилдоогүй, махан биеийн бус, мөн мэдээж нийгмийн арга замуудыг хэрэглэдэггүй, хүний бодол, үзлийг агуулдаггүй, түүнчлэн хүний амьдралын гүн ухаантай хамаагүй ажлыг хийж чадна. Энэ нь бие махбодтой болсон Бурханы хийхээр зорьдог ажил бөгөөд энэ нь бас Бурхан бие махбодтой болохын бодит ач холбогдол юм. Бурхан бусад ялихгүй үйл явцыг туулалгүйгээр

үндсэндээ махбодоор хийх хэрэгтэй ажлын үе шатыг хийхийн тулд махбодод ирдэг бөгөөд Түүнд хэвийн хүний туршлага байдаггүй. Бурханы махбод болсон биеийн хийх хэрэгтэй ажил нь хэвийн хүний туршлагыг агуулдаггүй. Иймээс Бурхан махбодоор биелүүлэх хэрэгтэй ажлаа гүйцэлдүүлэхийн төлөө л махбодод ирдэг. Үлдсэн нь Түүнтэй ямар ч хамаагүй. Тэр маш олон ялихгүй үйл явцыг туулдаггүй. Түүний ажил дуусмагц бие махбодтой болохын ач холбогдол нь ч бас төгсдөг. Энэ үе шатыг дуусгах гэдэг нь махбодоор хийх хэрэгтэй Түүний ажил гүйцэлдсэн, Түүний махбодын үйлчлэл гүйцсэн гэсэн үг юм. Гэхдээ Тэр махбодод хязгааргүй хугацаагаар ажиллаад байж болохгүй. Тэр ажиллахын тулд өөр газар луу буюу махбодын гадна орших газар луу шилжих ёстой. Ийм маягаар л Түүний ажил бүрэн биелж, илүү их үр нөлөө үзүүлж чадна. Бурхан Өөрийн анхдагч төлөвлөгөөний дагуу ажилладаг. Ямар ажил хийх хэрэгтэйг болон ямар ажил гүйцэлдүүлснээ Тэр гарын арван хуруу шигээ тодорхой мэддэг. Бурхан Өөрийн аль хэдийн урьдчилан тодорхойлсон замаар алхахад нь хүн нэг бүрийг хөтөлдөг. Хэн ч үүнээс зугтаж чадахгүй. Бурханы Сүнсний удирдамжийг дагадаг хүмүүс л амралтад орж чадна. Магадгүй хожмын ажилд хүнийг залж чиглүүлэхийн тулд Бурхан махбодоор ярихгүй, харин биет хэлбэртэй Сүнс хүний амьдралыг залж чиглүүлнэ. Тэр үед л хүн Бурханд бодитоор хүрч, Бурханыг харж чадах ба бодитой Бурханаар төгс болгуулахын тулд Бурханы шаарддаг бодит байдалд илүү сайн орж чадна. Энэ нь Бурханы биелүүлэхээр зорьж буй ажил, Түүний аль эртнээс төлөвлөсөн зүйл юм. Үүнээс та бүхэн өөрсдийн явах ёстой замыг харах ёстой!

ХАРАНХУЙН НӨЛӨӨНӨӨС АНГИЖИР, ТЭГВЭЛ ЧИ БУРХАНААР АВХУУЛНА

Харанхуйн нөлөө гэж юу вэ? “Харанхуйн нөлөө” гэдэг нь Сатан хүмүүсийг мэхэлж, завхруулж, хүлж, хянадаг нөлөө юм; Сатаны нөлөө бол үхлийн уур амьсгалтай нөлөө. Сатаны эзэмшилд амьдардаг бүх хүн мөхөх тавилантай. Бурханд итгэдэг болсныхоо дараа харанхуйн нөлөөнөөс хэрхэн ангижрах вэ? Бурханд чин сэтгэлээсээ залбирсныхаа дараа чи зүрх сэтгэлээ Түүн рүү бүрэн хандуулж, энэ үед Бурханы Сүнс зүрх сэтгэлийг чинь хөдөлгөдөг. Чи өөрийгөө Түүнд бүрэн зориулах хүсэлтэй болдог ба энэ мөчид чи харанхуйн нөлөөнөөс ангижирсан байдаг. Хэрвээ хүний хийдэг бүхэн Бурханы таалалд нийцэж, Түүний шаардлагуудыг хангадаг бол тухайн хүн Бурханы үгээр, Бурханы халамж, хамгаалалт дор амьдардаг хүн юм. Хэрвээ хүмүүс Бурханы үгийг хэрэгжүүлж чадахгүй, Түүнийг байнга хууран мэхлэх гэж оролддог, Түүнд хааш яаш байдлаар ханддаг, оршин тогтнолд нь итгэдэггүй аваас ийм хүмүүс бүгд харанхуйн нөлөөн дор амьдарч буй хэрэг юм. Бурханы авралыг хүлээн аваагүй хүмүүс бүгд Сатаны эзэмшил дор амьдарч байгаа; өөрөөр хэлбэл, тэд бүгд харанхуйн нөлөөн дор

амьдардаг. Бурханд итгэдэггүй хүмүүс Сатаны эзэмшил дор амьдарч байгаа. Бурханы оршин тогтнолд итгэдэг хүмүүс ч гэсэн Бурханы гэрэлд заавал амьдарч байх албагүй, учир нь Түүнд итгэдэг хүмүүс үнэндээ Түүний үгээр амьдардаг, эсвэл Бурханыг дуулгавартай дагаж чаддаг хүмүүс биш байх магадлалтай. Хүн Бурханд итгэхээс хэтэрдэггүй бөгөөд тэрээр Бурханыг мэддэггүй учраас аанай л хуучин дүрэм журмаар, үхмэл үгс дунд, харанхуй, тодорхойгүй амьдралаар амьдарч, Бурханаар бүрэн ариусгагдаагүй, бүрмөсөн авхуулаагүй байна. Иймээс Бурханд итгэдэггүй хүмүүс харанхуйн нөлөөн дор амьдардаг нь хэлүүлэлтгүй ойлгомжтой боловч Бурханд итгэдэг хүмүүс хүртэл Ариун Сүнс өөрсөд дээр нь ажиллаагүйн улмаас харанхуйн нөлөөн дор амьдарсаар байдаг. Бурханы нигүүлсэл, Бурханы өршөөлийг хүлээн аваагүй хүмүүс болон Ариун Сүнсний ажлыг харж чаддаггүй хүмүүс бүгд харанхуйн нөлөөнд амьдардаг; Бурханы нигүүлслийг эдэлдэг мөртөө Түүнийг мэддэггүй хүмүүс ч бас ихэнхдээ харанхуйн нөлөөнд амьдарч байгаа. Хэрвээ хүн Бурханд итгэдэг ч амьдралынхаа ихэнхийг харанхуйн нөлөөнд өнгөрүүлбэл тухайн хүний оршин тогтнол утга учраа алдчихсан байдаг тул Бурхан оршин байдагт итгэдэггүй хүмүүсийг бол ярихын ч хэрэггүй юм.

Бурханы ажлыг хүлээн зөвшөөрдөггүй юм уу Бурханы ажлыг хүлээн зөвшөөрдөг боловч Түүний шаардлагад нийцэж чаддаггүй бүх хүн харанхуйн нөлөөн дор амьдардаг. Үнэнийг эрэлхийлдэг, Бурханы шаардлагад нийцэж чаддаг хүмүүс л Түүнээс ерөөл хүлээн авч, харанхуйн нөлөөнөөс ангижирна. Чөлөөлөгдөөгүй, зарим зүйлээр үргэлж удирдуулж байдаг, Бурханд зүрх сэтгэлээ өгч чадахгүй байгаа хүмүүс бол Сатанд боолчлогдон, үхлийн уур амьсгалд амьдарч байгаа хүмүүс юм. Үүрэгтээ үнэнч бус, Бурханы даалгаварт үнэнч бус, чуулган дахь чиг үүргээ гүйцэтгэдэггүй хүмүүс харанхуйн нөлөөн дор амьдарч байна. Чуулганы амьдралыг санаатайгаар үймүүлдэг, ах эгч нарын хоорондын харилцааг зориуд сүйтгэдэг, эсвэл өөрсдийн бүлгийг бүрдүүлдэг хүмүүс бүр гүн харанхуйн нөлөөн дор, Сатаны боолчлолд амьдардаг. Бурхантай хэвийн бус харилцаатай, үргэлж хэрээс хэтэрсэн юм хүсдэг, үргэлж ашиг хонжоо олохыг хүсдэг, өөрсдийн зан чанарыг өөрчлөхөөр огтхон ч эрж хайдаггүй хүмүүс бол харанхуйн нөлөөн дор амьдардаг хүмүүс юм. Үнэнийг хэрэгжүүлэхдээ үргэлж хайнга, нухацтай бус байж, Бурханы хүсэлд нийцүүлэхийг хичээдэггүй, оронд нь өөрсдийн махан биеийг л хангахыг хичээдэг хүмүүс ч бас харанхуйн нөлөөн дор, үхэлд ороогдон амьдарч байгаа хүмүүс билээ. Бурханы төлөө ажиллахдаа шударга бус байдал, заль мэх ашигладаг, Бурхантай хааш яаш байдлаар харьцдаг, Бурханыг хуурч мэхэлдэг, үргэлж хувиа хичээдэг хүмүүс бол харанхуйн нөлөөн дор амьдарч байгаа хүмүүс юм. Бурханыг чин сэтгэлээсээ хайрлаж чаддаггүй, үнэнийг эрэлхийлдэггүй, зан чанараа өөрчлөхөд анхаарлаа төвлөрүүлдэггүй бүх хүн харанхуйн нөлөөн дор амьдардаг.

Хэрвээ чи Бурханы сайшаалыг хүртэхийг хүсдэг бол эхлээд Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижирч, зүрх сэтгэлээ Бурханд нээж, Бурхан руу бүрэн хандуулах ёстой. Чиний одоо хийж байгаа зүйлсийг Бурхан сайшаах уу? Чи зүрх сэтгэлээ

Бурхан руу хандуулсан уу? Хийсэн бүхэн чинь Бурханы чамаас шаардсан зүйлс мөн үү? Тэдгээр нь үнэнд нийцдэг үү? Чи цаг ямагт өөрийгөө шалган нягталж, Бурханы үгийг идэж уухдаа төвлөрч, Түүний өмнө зүрх сэтгэлээ дэлгэж, Түүнийг чин сэтгэлээсээ хайрлаж, Бурханы төлөө өөрийгөө үнэнчээр зарлагадах ёстой. Тийм хүмүүс Бурханы сайшаалыг хүлээн авах нь лавтай. Бурханд итгэдэг атлаа үнэнийг эрэлхийлдэггүй бүх хүн Сатаны нөлөөнөөс ангижрах аргагүй байдаг. Үнэнч шударгаар амьдардаггүй, бусдын өмнө нэг янзаар аашилж, харин ар хударгаар нь өөрөөр авирладаг, гаднаа даруу төлөв, тэвчээртэй, хайр энэрэлтэй мөртөө мөн чанартаа зусар зальхай, ов мэхтэй, Бурханд үнэнч биш хүмүүс бол харанхуйн нөлөөн дор амьдарч буй хүмүүсийн нийтлэг төлөөлөл юм. Тэд бол хорт могойн төрлийн хүмүүс мөн. Зөвхөн өөрсдийн ашиг тусын төлөө Бурханд итгэдэг, өөрсдийгөө зөвтгөдөг, их зантай, онгироо сагсуу, байр сууриа хамгаалдаг хүмүүс бол Сатаныг хайрлаж, үнэнийг эсэргүүцдэг хүмүүс билээ. Тэд бол Бурханыг эсэргүүцдэг, Сатанд бүрэн харьяалагддаг хүмүүс юм. Бурханы ачааг боддоггүй, Бурханд үнэн сэтгэлээсээ үйлчилдэггүй, өөрсдийн ашиг сонирхол болон гэр бүлийнхээ ашиг сонирхолд байнга санаа тавьдаг, Бурханы төлөө өөрсдийгөө зарлагадахын тулд бүхнийг орхих чадваргүй, Түүний үгээр хэзээ ч амьдардаггүй хүмүүс Бурханы үгийн гадна амьдарч байгаа юм. Тийм хүмүүс Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй.

Бурхан хүмүүсийг бүтээхдээ тэдэнд Өөрийн баялгийг эдлүүлж, Өөрийгөө тэднээр үнэхээр хайрлуулахын төлөө байсан; ийм маягаар хүмүүс Түүний гэрэлд амьдрах байлаа. Өнөөдөр Бурханыг хайрлаж чаддаггүй, Түүний ачааг боддоггүй, Бурханд зүрх сэтгэлээ бүрэн өгч чаддаггүй, Бурханы зүрх сэтгэлийг өөрсдийн мэт авч үздэггүй, Бурханы ачааг өөрсдийн мэт үүрэлцэж чаддаггүй хүмүүсийн дээр Бурханы гэрэл гэрэлтдэггүй, тиймээс тэд бүгд харанхуйн нөлөөн дор амьдарч байгаа. Тэд Бурханы хүслийг эрс эсэргүүцдэг зам дээр байдаг бөгөөд хийдэг бүхэнд нь өчүүхэн ч үнэн байдаггүй. Тэд Сатантай хамт шалбаагт хөлбөрдөг. Тэд бол харанхуйн нөлөөн дор амьдарч буй хүмүүс юм. Хэрвээ чи Бурханы үгийг үргэлж идэж уун, Түүний хүсэлд анхаарал тавьж, Түүний үгийг хэрэгжүүлдэг бол Бурханд харьяалагдаж, Бурханы үгсээр амьдардаг хүн юм. Чи Сатаны эзэмшлээс ангижирч, Бурханы гэрэлд амьдрахыг хүсэж байна уу? Хэрвээ чи Бурханы үгсээр амьдардаг бол Ариун Сүнс ажлаа хийх боломжтой болно; хэрвээ чи Сатаны нөлөөн дор амьдардаг бол Ариун Сүнсэнд тийм боломж олгохгүй. Хүмүүс дээр Ариун Сүнсний хийдэг ажил, хүмүүсийн дээр Түүний гэрэлтүүлдэг гэрэл, хүмүүст Түүний өгдөг итгэл хормын төдий л үргэлжилдэг; хэрвээ хүн анхаарал, болгоомжгүй байвал Ариун Сүнсний хийдэг ажил хажуугаар нь өнгөрөх болно. Хэрвээ хүмүүс Бурханы үгээр амьдардаг бол Ариун Сүнс тэдэнтэй хамт байж, тэдэн дээр ажиллана. Хэрвээ хүмүүс Бурханы үгээр амьдрахгүй байгаа бол Сатаны боолчлолд амьдардаг. Ялзарсан зан чанартай амьдардаг хүмүүстэй Ариун Сүнс хамт байдаггүй, эсвэл тэдэнд Ариун Сүнсний ажил байдаггүй. Хэрвээ чи Бурханы үгийн хүрээнд амьдарч буй бол, мөн Бурханы шаарддаг байдалд амьдардаг бол Түүнд харьяалагддаг ба Тэр чам дээр ажиллана; хэрвээ чи Бурханы

шаардлагын хил хязгаар дотор амьдардаггүй, харин Сатаны эзэмшил дор амьдардаг бол Сатаны ялзрал дор амьдардаг чинь маргаангүй. Бурханы үгээр амьдарч, Түүнд зүрх сэтгэлээ өгснөөр л чи Түүний шаардлагад нийцэж чадна; чи Бурханы хэлснээр хийж, Бурханы айлдварыг оршин тогтнолынхоо үндэс, амьдралынхаа бодит байдал болгох ёстой бөгөөд тэр үед л чи Бурханд харьяалагдана. Хэрвээ чи үнэхээр Бурханы хүслийн дагуу хэрэгжүүлбэл Тэр чам дээр ажиллаж, чи Бурханы ерөөл дор, Бурханы дүр төрхийн гэрэлд амьдарч, Ариун Сүнсний хийдэг ажлыг ухаарч, Бурхантай хамт байхын баяр хөөрийг мэдэрнэ.

Харанхуйн нөлөөнөөс ангижрахын тулд чи эхлээд Бурханд үнэнч байж, зүрх сэтгэлдээ үнэнийг эрэлхийлэх хүсэл эрмэлзэлтэй байх ёстой; тэгсэн цагт л чи зөв байдалтай байх болно. Зөв байдалтай амьдрах нь харанхуйн нөлөөнөөс ангижрах урьдчилсан нөхцөл юм. Зөв байдалгүй байна гэдэг нь чи Бурханд үнэнч бус бөгөөд зүрх сэтгэлдээ үнэнийг эрэлхийлэх хүсэл эрмэлзэлгүй гэсэн үг. Тэгвээс харанхуйн нөлөөнөөс ангижрах талаар ярихын ч хэрэггүй. Миний үг бол хүн харанхуйн нөлөөнөөс ангижрах үндэс суурь бөгөөд Миний үгийн дагуу хэрэгжүүлж чаддаггүй хүмүүс харанхуйн нөлөөний боолчлолоос ангижирч чадахгүй. Зөв байдалтай амьдрах гэдэг нь Бурханы үгийн удирдамж дор амьдрах, Бурханд үнэнч байдалтай амьдрах, үнэнийг эрж хайх байдалтай амьдрах, Бурханы төлөө чин сэтгэлээсээ өөрийгөө зориулах бодит байдалд амьдрах, Бурханыг чин сэтгэлээсээ хайрлах байдалтай амьдрах явдал юм. Эдгээр байдал болон энэ бодит байдал дотор амьдардаг хүмүүс үнэн рүү гүн орох тусмаа аажмаар өөрчлөгдөнө. Тэд ажил лавшрахын хэрээр өөрчлөгдөж, эцэст нь Бурханаар гарцаагүй авхуулах, Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг хүн болно. Харанхуйн нөлөөнөөс ангижирсан хүмүүс Бурханы хүслийг яваандаа олж мэдэн, Бурханы хүслийг алхам алхмаар ойлгож, эцэстээ Бурханы ойр дотнын хүн болно. Тэд Бурханы тухай үзэл тээдэггүй, Түүний эсрэг тэрсэлдэггүйгээр үл барам, урьд нь өөрсдийг нь эзэмдэж байсан үзэл, тэрслүү занг улам их жигшдэг ба тэдний зүрх сэтгэлд Бурханыг гэх жинхэнэ хайр бий болдог. Харанхуйн нөлөөнөөс ангижирч чаддаггүй хүмүүс махан биедээ бүрэн эзэмдүүлдэг ба тэрслүү зангаар дүүрэн байдаг; тэдний зүрх сэтгэл хүний үзэл, амьдралын гүн ухаан болон өөрсдийнх нь санаа зорилго, төлөвлөгөөгөөр дүүрдэг. Бурхан хүнээс нэгэн сэтгэлийн хайрыг шаарддаг; Тэрээр юу шаарддаг гэхээр хүнийг Өөрийнх нь үгээр бодлоо дүүргэж, Түүнийг гэх зүрх дүүрэн хайранд эзэмдүүлэхийг шаарддаг. Бурханы үгээр амьдрах, Түүний үгэн дотроос хүний эрж хайх ёстой зүйлийг хайх, үгийнх нь төлөө Бурханыг хайрлах, Бурханы үгийн төлөө гүйх, Бурханы үгийн төлөө амьдрах—эдгээр нь бүгд хүний хүрэхээр зүтгэх ёстой зорилго юм. Бүх зүйл Бурханы үгэнд үндэслэн бий болох ёстой; ингэснээр л хүн Бурханы шаардлагуудад нийцэж чадна. Хэрвээ хүн Бурханы үгээр зэвсэглээгүй бол Сатанд эзэмдүүлсэн өт хорхойноос өөрцгүй билээ! Бодоод үз: Бурханы хэчнээн үг чиний дотор үндэслэсэн бэ? Чи ямар зүйл дээр Бурханы үгийн дагуу амьдарч байгаа вэ? Чи ямар зүйл дээр Бурханы үгийн дагуу амьдраагүй вэ? Хэрвээ

Бурханы үг чамайг бүрэн эзэмдээгүй бол яг юу зүрх сэтгэлийг чинь эзэмддэг юм бэ? Өдөр тутмын амьдралдаа чи Сатанд захирагдаж байна уу, эсвэл Бурханы үгэнд эзэмдүүлж байна уу? Чиний залбирал Түүний үгэнд суурилдаг уу? Чи Бурханы үгийн гэгээрлээр дамжуулан сөрөг байдлаасаа гарсан уу? Бурханы үгийг оршин тогтнолынхоо суурь болгох нь хүн бүрийн орох ёстой зүйл юм. Хэрвээ чиний амьдралд Бурханы үг байхгүй бол чи харанхуйн нөлөөн дор амьдарч байгаа бөгөөд Бурханд тэрсэлж, Бурханыг эсэргүүцэж, Түүний нэрийг гутааж байна. Ийм хүмүүс Бурханд итгэх нь тэр чигтээ дурааараа аашилж, үймүүлж байгаа хэрэг. Чи амьдралынхаа хэр ихийг Түүний үгийн дагуу амьдарч өнгөрүүлсэн бэ? Чиний амьдралын хэдий хэр нь Түүний үгийн дагуу байгаагүй вэ? Бурханы үгийн чамаас шаардсан зүйлсийн хэр их нь чамд биеллээ олсон бэ? Хэр их нь биелээгүй вэ? Чи эдгээр зүйлийг нарийн шалгаж үзсэн үү?

Харанхуйн нөлөөнөөс ангижрахад нэг талаас Ариун Сүнсний ажил, нөгөө талаас хүний чин сэтгэлийн хамтын ажиллагаа шаардлагатай. Хүн зөв замд ороогүй байна гэж Би яагаад хэлдэг вэ? Зөв замд орсон хүмүүс юун түрүүнд зүрх сэтгэлээ Бурханд өгч чадна. Энэ бол ороход маш удаан хугацаа шаардагддаг даалгавар юм, учир нь хүн төрөлхтөн үргэлж харанхуйн нөлөөн дор амьдарсаар ирсэн бөгөөд Сатаны боолчлолд хэдэн мянган жил байсаар ирсэн. Тиймээс энэ оролтод ганц хоёрхон хоногийн дотор хүрч чадахгүй. Хүмүүс өөрсдийн байр байдлыг ойлгоосой гэсэндээ Би энэ асуудлыг өнөөдөр хөндлөө; харанхуйн нөлөө гэж юу болох, гэрэл дотор амьдрах гэж юу болохыг хүн ялган таньж чаддаг болох үед оролт хавьгүй амархан болдог. Яагаад гэвэл, Сатаны нөлөөнөөс ангижрахаасаа өмнө Сатаны нөлөө гэж юу болохыг чи мэдэх ёстой; ингэсний дараа л чи үүнээс ангижрах замыг олно. Түүнээс хойш юу хийх вэ гэдэг бол хүний өөрийнх нь асуудал. Бүх зүйл рүү эерэг талаас ор, хэзээ ч бүү идэвхгүйгээр хүлээ. Ийм маягаар л чи Бурханаар авхуулж чадна.

БУРХАНД ИТГЭХДЭЭ ШАШНЫ ЗАН ҮЙЛД БИШ БОДИТ БАЙДАЛД АНХААРЛАА ХАНДУУЛАХ ЁСТОЙ

Чи шашны хэдэн зан үйл мөрддөг вэ? Чи хэдэн удаа Бурханы үгийн эсрэг тэрсэлж, өөрийнхөөрөө хийж байсан бэ? Бурханы ачаанд үнэхээр анхаарал хандуулж, Түүний хүслийг биелүүлэхийг эрэлхийлдгээсээ болоод чи хэдэн удаа Бурханы үгийг хэрэгжүүлж байсан бэ? Чи Бурханы үгийг ойлгож, хэрэгжүүлэх ёстой. Өөрийн бүх үйлдэл, үйл хэрэгт зарчимтай бай, гэхдээ энэ нь дүрэмд баригдах юм уу зөвхөн нүд хуурахын тулд арай ядан хийх явдал биш; харин Бурханы үгээр амьдарч, үнэнийг хэрэгжүүлнэ гэсэн үг юм. Ийм хэрэгжүүлэлт л Бурханыг хангалуун байлгадаг. Бурханы таалалд нийцэх аливаа үйл ажиллагаа нь дүрэм

биш, харин үнэний хэрэгжүүлэлт билээ. Зарим хүн олны анхаарлыг өөртөө татах дуртай байдаг. Ах эгч нарынхаа дэргэд Бурханд өртэй гэж ярьдаг ч ар хударгаар нь үнэнийг хэрэгжүүлэлгүй, шал эсрэгээр нь хийдэг. Тэд шашны фарисайчууд биш гэж үү? Бурханыг үнэн голоосоо хайрладаг, үнэнтэй хүн нь Бурханд үнэнч нэгэн боловч үүнийгээ ил гаргадаггүй. Асуудал үүсэхэд тэрээр үнэнийг хэрэгжүүлэхэд бэлэн байдаг ба мөс чанарынхаа эсрэг үг, үйлдэл хийдэггүй. Орчин нөхцөл ямар ч байсан хамаагүй, асуудал үүсэх үед тэрээр мэргэн ухаанаа харуулдаг, үйл хэрэгтээ зарчимтай байдаг. Ийм хүн л жинхэнээсээ үйлчилдэг нэгэн юм. Бурханд өртэй тухайгаа үргэлж дүр эсгэдэг хүмүүс байдаг; тэд өдөржин санаа зовнисон байдлаар хөмсгөө зангидаж, дүр эсгэн, өрөвдөлтэй царайлж өдөр хоногоо өнгөрүүлдэг. Хэчнээн жигшүүртэй гээч! “Бурханд ямар өртэй тухайгаа надад хэлж болох уу?” гэж асуувал тэд хэлэх үггүй болно. Хэрвээ чи Бурханд үнэнч бол гаднаа энэ талаар бүү ярь; харин бодит хэрэгжүүлэлтээр Бурханыг гэх хайраа харуулж, чин үнэнч сэтгэлээр Түүнд залбир. Бурхантай үг хэлээрээ, хааш яаш л харьцдаг хүмүүс бол бүгд хоёр нүүртнүүд! Зарим нь залбирах болгондоо Бурханд өртэйгөө ярьж, Ариун Сүнс хөдөлгөөгүй байхад хүртэл залбирах бүрдээ мэгшин уйлж эхэлдэг. Ийм хүмүүс шашны зан үйл болон үзэлтэй байдаг; тэд ийм зан үйл, үзлээр амьдран, ийм үйлдлийг Бурхан таалдаг, бас өнгөц сүсэг бишрэл, гунигт нулимс бол Бурхан таашаадаг зүйл гэдэгт үргэлж итгэдэг. Ийм хөгийн хүмүүсээс ямар сайн юм гарах билээ? Зарим нь даруу байдлаа харуулахын тулд бусдын дэргэд ярих үедээ журамтай дүр үзүүлдэг. Зарим нь бусдын өмнө ямар ч хүч чадалгүй хурга адил зориуд зусарддаг. Хаанчлалын ардуудад тохирох төрх байдал энэ мөн үү? Хаанчлалын ардууд цог золбоотой агаад эрх чөлөөтэй, гэм зэмгүй агаад нээлттэй, үнэнч агаад хайр татам байж, эрх чөлөөтэй амьдардаг байх ёстой. Тэд жудагтай, нэр төртэй, хаашаа ч явсан гэрчлэлд зогсож чаддаг байх ёстой; тийм хүмүүсийг Бурхан болон хүмүүсийн аль аль нь хайрладаг. Шинээр итгэж байгаа хүмүүс гадаад талын хэт олон хэрэгжүүлэлттэй байдаг; тэд эхлээд харьцалт, эвдэлтийн үеийг туулах ёстой. Зүрх сэтгэлдээ Бурханд итгэдэг хүмүүс гаднаа бусдаас ялгардаггүй, гэвч үйлдэл болон үйл хэрэг нь бусдад магтууштай байдаг. Ийм хүмүүсийг л Бурханы үгийг амьдран харуулж байна гэж үзэж болно. Хэрвээ чи өдөр болгон энэ, тэр хүнд сайн мэдээ номлож, тэднийг аврал руу аваачдаг ч эцсийн эцэст дүрэм, сургаал дотор амьдарч байгаа бол Бурханд алдрыг авчирч чадахгүй. Ийм хүмүүс бол шашны хүмүүс, бас хоёр нүүртнүүд юм. Шашны хүмүүс цугларах болгондоо “Эгч минь, ойрд та ямаршуухан байв даа?” гэж асуудаг. Эгч хариуд нь, “Би Бурханд өртэй, бас Түүний хүслийг биелүүлж чадахгүй байгаа юм шиг санагддаг” гэдэг. Өөр нэг нь “Би ч гэсэн Бурханд өртэй, бас Түүнийг хангалуун байлгаж чаддаггүй” гэж хэлдэг. Энэ цөөн хэдэн үг, өгүүлбэр л дангаараа тэдний зүрх сэтгэлийн гүн дэх бузар булай зүйлсийг илэрхийлдэг; ийм үг хамгийн жигшүүртэй, дэндүү ой гутам байдаг. Ийм хүмүүсийн уг чанар Бурханыг эсэргүүцдэг. Бодит байдалд анхаарлаа хандуулдаг хүмүүс зүрх сэтгэл доторх бүхнээ ярилцаж, нөхөрлөлдөө яриандаа

өөрсдийн зүрх сэтгэлийг уудалж байдаг. Үүнд ганц ч худал ааль аяг, ёсорхуу байдал, хоосон нялуун үг гэж байхгүй. Тэд үргэлж шулуун шударга байж, ертөнцийн дүрэм журамд захирагддаггүй. Ямар ч мэдрэмжгүй ч гэлээ, гаднаа гаргаж үзүүлэх дуртай хүмүүс байдаг. Өөр хэн нэгнийг дуулах үед тэд саван дахь будаа нь аль хэдийн түлэгдсэнийг ч анзааралгүй бүжиглэж эхэлдэг. Ийм хүмүүс нь үнэн сүсэгт, хүндлүүштэй бус, хэтэрхий хөнгөмсөг байдаг. Энэ бүх зүйл бол бодит байдлаас тасарсны илрэл юм. Зарим хүн сүнслэг амийн хэрэг явдлын талаар ярилцах үедээ хэдий Бурханд өртэйгөө ярьдаггүй ч зүрх сэтгэл дотроо Түүнийг гэсэн жинхэнэ хайрыг тээж байдаг. Бурханд өртэй чинь бусадтай ямар ч хамаагүй; чи хүнд биш, Бурханд өртэй. Тэгэхээр энэ тухай бусдад байнга ярих ямар хэрэгтэй юм бэ? Чи гаднах чармайлт, илэрхийлэлд биш, харин бодит байдалд ороход анхаарлаа хандуулах ёстой. Хүмүүсийн өнгөц сайн үйл хэрэг юуг төлөөлдөг вэ? Тэдгээр нь махан биеийг төлөөлдөг ба хамгийн сайн гадаад талын хэрэгжүүлэлт ч амийг бус, харин хувийн зан чанарыг чинь л төлөөлдөг. Хүний гадаад талын хэрэгжүүлэлт Бурханы хүслийг биелүүлж чадахгүй. Чи байнга Бурханд өртэй тухайгаа ярьдаг ч бусдын амийг хангаж, Бурханыг хайрлахад бусдыг өдөөж чаддаггүй. Чиний ийм үйлдлүүд Бурханыг сэтгэл хангалуун байлгана гэж чи итгэж байна уу? Энэ нь Бурханы хүсэл, энэ нь сүснийх гэж чи боддог боловч үнэн хэрэгтээ энэ чинь утгагүй зүйл! Чиний таашаадаг, хүсдэг зүйл бол Бурханыг баясгадаг зүйл гэж чи үздэг. Чиний таашаадаг зүйл Бурханыг төлөөлж чадах уу? Хүний зан авир Бурханыг төлөөлж чадах уу? Чиний таашаадаг зүйл бол яг Бурханы үзэн яддаг зүйл бөгөөд чиний зуршлууд бол Бурханы жигшин голдог зүйл юм. Хэрвээ чамд өртэй санагдвал Бурханы өмнө очиж залбир. Энэ талаар бусдад ярих ямар ч хэрэггүй. Хэрвээ чи Бурханы өмнө залбиралгүй, оронд нь бусдын анхаарлыг байнга өөртөө татдаг бол энэ чинь Бурханы хүслийг биелүүлж чадах уу? Хэрвээ чиний үйлдэл үргэлж нүд хуурахаас цаашгүй байдаг бол чи дээд зэргийн нэрэлхүү гэсэн үг. Өнгөц сайн үйл л хийдэг, бодит байдалгүй хүмүүс ямар байдалтай хүмүүс вэ? Ийм хүмүүс бол зүгээр л хоёр нүүртэй фарисайчууд, шашны хүмүүс юм! Хэрвээ та нар гадаад талын хэрэгжүүлэлтийг хойш тавьж, өөрчлөлт хийж чадахгүй бол та нарт байгаа хоёр нүүртэй зангийн элементүүд улам ихэснэ. Хоёр нүүртэй зангийн элементүүд хэдий чинээ ихэснэ, Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл төдий чинээ их байдаг. Эцэст нь ийм хүмүүс гарцаагүй таягдан хаягдана!

БУРХАНЫ ӨНӨӨДРИЙН АЖЛЫГ МЭДДЭГ ХҮМҮҮС Л БУРХАНД ҮЙЛЧИЛЖ БОЛНО

Бурханд гэрчлэл хийж, агуу улаан лууг шившиглэхийн тулд хүн зарчимтай байх ёстой, мөн нэг нөхцөлийг хангаж байх ёстой: Хүн зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлаж, Түүний үг рүү орох ёстой. Хэрвээ чи Бурханы үг рүү орохгүй бол Сатаныг

шившиглэх ямар ч аргагүй байх болно. Амь чинь өссөнөөр чи агуу улаан лууг орхиж, түүнд туйлын их доромжлол авчирдаг; энэ нь л агуу улаан лууг үнэхээр шившиглэж байгаа хэрэг юм. Чи Бурханы үгийг хэрэгжүүлэхийг хэдий чинээ их хүснэ, Бурханыг гэх хайр, агуу улаан лууг гэх үзэн ядалт чинь төдий чинээ нотлогддог; чи Бурханы үгэнд дуулгавартай байх тусам, үнэнийг хүсэн эрмэлздэг чинь төдий чинээ батлагддаг. Бурханы үгийг хүсэн эрмэлздэггүй хүмүүс бол амьгүй хүмүүс юм. Тийм хүмүүс бол Бурханы үгийн гаднах, шашинд харьяалагддаг хүмүүс билээ. Бурханд үнэхээр итгэдэг хүмүүс Бурханы үгийг идэж, ууснаар дамжуулан үгийнх нь талаар илүү гүн гүнзгий мэдлэгтэй байдаг. Хэрвээ чи Бурханы үгийг хүсэн эрмэлздэггүй бол Бурханы үгийг жинхэнээсээ идэж, ууж чадахгүй бөгөөд Бурханы үгийн талаар ямар ч мэдлэггүй бол Бурханыг гэрчилж, сэтгэлийг нь хангалуун болгох ямар ч аргагүй байна.

Бурханд итгэхдээ хүн Бурханыг хэрхэн мэдэх ёстой вэ? Хүн гажуудал, төөрөгдөлгүйгээр өнөөдрийн Бурханы үг, ажилд үндэслэн Бурханыг мэдэж авах ёстой ба юун түрүүнд Бурханы ажлыг мэдэх ёстой. Энэ бол Бурханыг мэдэх суурь юм. Бурханы үгийг хольцгүйгээр ойлгодоггүй тэр бүх олон янзын гажууд онол бол шашны үзэл юм; тэдгээр нь гажууд, эндүү ташаа ойлголт билээ. Шашны хүмүүсийн хамгийн агуу ур чадвар бол урьд нь ойлгосон Бурханы үгийг авч, өнөөдрийн Бурханы үгтэй харьцуулан шалгадаг явдал юм. Хэрвээ өнөөдрийн Бурханд үйлчилж байхдаа чи Ариун Сүнсний урьдын гэгээрлээр илчлэгдсэн зүйлстэй зууралдвал үйлчлэл чинь саад учруулж, хэрэгжүүлэлт чинь хоцрогдож, шашны зан үйлээс цаашгүй болно. Бурханд үйлчилдэг хүмүүс бусад чанаруудын дундаас гаднаа даруухан, тэвчээртэй байх ёстой гэж чи итгэдэг бөгөөд ийм төрлийн мэдлэгийг өнөөдөр хэрэгжүүлдэг бол тийм мэдлэг нь шашны үзэл; тийм хэрэгжүүлэлт нь хоёр нүүртэй гүйцэтгэл болжээ. “Шашны үзэл” гэх хэллэг нь хоцрогдсон, үеэ өнгөрөөсөн зүйлсийг (урьд нь Бурханы хэлсэн үг болон Ариун Сүнсний шууд илчилсэн гэрлийн тухай ойлголтыг оролцуулаад) хэлдэг бөгөөд хэрвээ тэдгээрийг өнөөдөр хэрэгжүүлбэл Бурханы ажлыг тасалдуулах ба хүнд ямар ч ашиг тус авчрахгүй. Хэрвээ хүмүүс өөрсдийн дотор байгаа, шашны үзэлд хамаарах тэдгээр зүйлээс ангижирч чадахгүй бол эдгээр зүйл Бурханд үйлчлэх үйлчлэлд нь асар их саад болно. Шашны үзэлтэй хүмүүс Ариун Сүнсний ажлын алхамуудтай хөл нийлүүлэх ямар ч аргагүй—тэд эхлээд нэг, дараа нь хоёр алхмын хойно хоцордог. Яагаад гэвэл, эдгээр шашны үзэл нь хүнийг ер бусын ихээр өөрийгөө зөвтгөдөг, биеэ тоосон зантай болгодог. Бурхан өнгөрсөн үед юу ярьж, хийж байснаа эргэн дурсдаггүй; ямар нэг зүйл хоцрогдсон л бол Тэр үүнийг таягдан хаядаг. Чи өөрийнхөө үзлийг үнэхээр орхиж чадахгүй гэж үү? Хэрвээ чи урьд нь Бурханы хэлсэн үгтэй зууралдвал Бурханы ажлыг мэддэг гэдгийг чинь энэ нь нотлох уу? Хэрвээ чи өнөөдөр Ариун Сүнсний гэрлийг хүлээн зөвшөөрч чадалгүй, оронд нь өнгөрсөн үеийн гэрэлтэй зууралдвал, Бурханы мөрийг дагадгийг чинь энэ нь баталж чадах уу? Чи шашны үзлийг орхиж чадахгүй л байна уу? Хэрвээ тийм бол чи Бурханыг эсэргүүцдэг хүн болно.

Хэрвээ хүмүүс шашны үзлийг орхиж чадах юм бол өнөөдрийн Бурханы үг, ажлыг хэмжихдээ оюун ухаанаа ашиглахгүй, харин шууд дуулгавартай дагана. Хэдийгээр өнөөдрийн Бурханы ажил өнгөрсөн үеийнхтэй илт адилгүй ч чи урьдын үзэл бодлоо орхин, өнөөдрийн Бурханы ажлыг шууд дуулгавартай дагаж чадна. Бурхан урьд нь хэрхэн ажиллаж байснаас үл хамааран Бурханы өнөөдрийн ажилд хамгийн чухал байр суурийг өгөх ёстой гэдгийг ойлгож чаддаг бол чи өөрийн үзлийг орхисон, Бурханыг дуулгавартай дагадаг, Бурханы ажил болон үгэнд дуулгавартай байж, Бурханы мөрийг дагаж чаддаг хүн юм. Ингэснээр чи Бурханыг үнэхээр дуулгавартай дагадаг нэгэн болох болно. Чи Бурханы ажлыг задлан шинжилж, нягтлан үздэггүй; яг л Бурхан өмнөх ажлаа мартсантай адил чи ч гэсэн үүнийг мартсан. Одоо бол одоо, өнгөрсөн бол өнгөрсөн бөгөөд өнөөдөр Бурхан урьд нь хийсэн зүйлээ хойш тавьсан болохоор чи энэ талаар бодох ёсгүй. Тийм хүн л Бурханыг бүрэн дүүрэн дуулгавартай дагадаг, шашны үзлээ бүрмөсөн орхисон хүн билээ.

Бурханы ажилд үргэлж шинэ хөгжил явагдаж байдаг учраас шинэ ажил гарч ирэхэд хоцрогдож, хуучирдаг ажил гэж бий. Хуучин ба шинэ эдгээр өөр өөр төрлийн ажил нь нэг нэгтэйгээ зөрчилддөггүй, харин харилцан бие биеэ нөхдөг; алхам бүр нь сүүлийн алхмаасаа үргэлжилдэг. Шинэ ажил байгаа учраас, хуучин зүйлс мэдээж таягдан хаягдах ёстой. Жишээ нь, аль эртнээс хэвшиж тогтсон хүний зарим хэрэгжүүлэлт болон дадал болсон үгс нь хүний олон жилийн туршлага, сургаалтай хослон хүний сэтгэлд элдэв янзын үзлийг бий болгожээ. Бурхан Өөрийн жинхэнэ царай болон төрөлх зан чанарыг хүнд хараахан бүрэн илчлээгүй нь эрт цагийн уламжлалт онолууд олон жилийн туршид түгэн дэлгэрсэнтэй хавсран хүний тийм үзэл бүрэлдэхэд илүү тааламжтай байсаар ирсэн юм. Бурханд итгэх хүний итгэлийн явцад янз бүрийн үзэл нөлөөлснөөр Бурханы талаарх элдэв янзын үзэл бүхий ойлголт хүмүүст тасралтгүй бий болж, хувьсан өөрчлөгдөхөд хүрсэн бөгөөд үүний үр дүнд Бурханд үйлчилдэг шашны олон хүн Түүний дайсан болсон гэж хэлж болох юм. Иймээс, хүмүүсийн шашны үзэл хүчтэй байх тусам Бурханыг улам эсэргүүцдэг ба төдий чинээ Бурханы дайснууд болдог. Бурханы ажил үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй; энэ нь хэзээ ч хоосон сургаалыг бий болгодоггүй, харин их бага хэмжээгээр тасралтгүй өөрчлөгдөн, шинэчлэгдэж байдаг. Ийм маягаар ажиллах нь Бурханы Өөрийн төрөлх зан чанарын илэрхийлэл билээ. Энэ нь бас Бурханы ажлын угийн зарчим бөгөөд Өөрийн удирдлагыг хэрэгжүүлдэг Бурханы арга барилын нэг юм. Хэрвээ Бурхан ийм маягаар ажиллаагүй бол хүн өөрчлөгдөхгүй, эсвэл Бурханыг мэдэж чадахгүй, Сатан ялагдахгүй байх байсан. Тиймээс, замбараагүй харагддаг ч үнэндээ тогтмол мөчлөгтэй тасралтгүй өөрчлөлтүүд Түүний ажилд гарч байдаг. Гэхдээ хүний Бурханд итгэдэг байдал нэлээд өөр. Хүн хуучны, танил сургаал болон системтэй зууралддаг бөгөөд тэдгээр нь хуучных байх тусам, төдий чинээ таатай байдаг. Хүний хад чулуу мэт өөрчлөгдөшгүй, мунхаг ухаан санаа Бурханы ойлгохын аргагүй шинэ ажил, үгийг

хэрхэн хүлээн авч чадах билээ? Үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй Бурханыг хүн үзэн яддаг; тэрээр хөгшин хөвөө, буурал үстэй, хөдөлгөөнгүй, хуучин Бурхандаа л дуртай. Тиймээс, Бурхан, хүн хоёрын аль алинд өөрсдийн гэсэн дуртай зүйл байдаг учраас хүн Бурханы дайсан болжээ. Бурхан шинэ ажлаа бараг зургаан мянган жилийн турш хийсээр ирсэн үе буюу өнөөдөр ч гэсэн энэ олон зөрчилдөөн оршсоор л байна. Тэгэхээр тэдгээр нь засаршгүй ажээ. Магадгүй энэ нь хүний зөрүүд зангаас, эсвэл Бурханы захиргааны зарлигийг хэн ч зөрчих аргагүйгээс болдог байх—гэхдээ тэдгээр шашны албан тушаалтнуудыг өгөршсөн хуучин ном, цаастай зууралдсаар байхад Бурхан дэргэд нь хэн ч байхгүй мэт дуусаагүй удирдлагын ажлаа хийдэг. Эдгээр зөрчилдөөн нь Бурхан, хүн хоёрыг дайснууд болгодог ба эвлэрэхийн аргагүй байдаг ч гэсэн Бурхан тэдгээрт огт анхаарал хандуулдаггүй, тийм зүйл байгаа ч юм шиг, байхгүй ч юм шиг ханддаг. Харин хүн итгэл, үзэлтэйгээ зууралдсаар, тэдгээрийгээ хэзээ ч орхидоггүй. Гэхдээ нэг зүйл илэрхий: Хэдий хүн байрнаасаа хазайдаггүй ч Бурханы хөл үргэлж хөдөлж, нөхцөл байдлаас хамааран байраа үргэлж өөрчилж байдаг. Эцэст нь хүн л ямар ч тэмцэлгүйгээр ялагдана. Харин Бурхан бол ялагдсан дайснуудынхаа хамгийн том дайсан нь, бас ялагдсан болон ялагдаагүй хүн төрөлхтний бүгдийнх нь аварга юм. Хэн Бурхантай тэмцэж, ялалт байгуулж чадах юм бэ? Хүний үзлийн ихэнх нь Бурханы ажлаас үүдэн гарсан учраас Бурханаас үүсэлтэй мэт санагддаг. Гэсэн ч үүнээс болоод Бурхан хүнийг уучилдаггүй, түүнчлэн Бурханы ажлаас үүдэн Бурханы ажилд хамааралгүй бүтээгдэхүүнийг багц багцаар нь “Бурханы төлөө” бүтээсэнд нь хүнийг магтаалаар булдаг ч үгүй. Харин ч Тэрээр хүний үзэл болон хуучин сүсэг бишрэлийг туйлын их зэвүүцдэг ба эдгээр үзэл анх гарч ирсэн хугацааг ч хүлээн зөвшөөрөх бодолгүй байдаг. Хүний үзлийг хүн түгээдэг учраас Өөрийнх нь ажлаас үүдэн эдгээр үзэл бий болсон гэдгийг Бурхан огтхон ч хүлээн зөвшөөрдөггүй; тэдгээрийн эх сурвалж нь хүний бодол, оюун ухаан бөгөөд Бурхан биш, харин Сатан юм. Бурханы санаа зорилго нь үргэлж Өөрийнхөө ажлыг хуучин үхмэл биш, харин шинэлэг, эрч хүчтэй байлгахын төлөө байсаар ирсэн ба хүнээр баримтлуулдаг зүйлс нь үүрд мөнхийн, хувиршгүй биш, харин эрин үе, цаг хугацааны хамтаар өөрчлөгддөг. Учир нь Тэр бол хүнийг үхүүлж, хуучинсаг байлгадаг диавол биш, харин амьдруулж, шинэлэг байлгадаг Бурхан билээ. Та нар үүнийг ойлгоогүй л байна уу? Хуучинсаг үзэл бодолтой учраас чи Бурханы тухай үзэлтэй байдаг бөгөөд тэдгээрийгээ хаяж чаддаггүй. Энэ нь, Бурханы ажилд эрүүл ухаан бараг байдаггүй, эсвэл Бурханы ажил хүний сэтгэл хөдлөлийг хайхардаггүйгээс болдог юм биш, түүнчлэн Бурхан үүргээ үргэлж цалгардуулдгаас ч болдог юм биш. Харин чи хэтэрхий дуулгаваргүй учраас, мөн чамд Бурханы бүтээлийн төрх өчүүхэн төдий ч байдаггүй учраас үзлээ орхиж чаддаггүй; Бурхан чамд хүндрэл учруулаад байдаг юм биш. Энэ бүхэн чамаас болсон ба Бурхантай ямар ч хамаагүй; бүх зовлон, золгүй явдлыг хүн бий болгодог. Бурханы бодол үргэлж сайн байдаг: Тэр чамайг үзэл бий болгоосой гэж хүсдэггүй, харин эрин үе өнгөрөхийн хэрээр

өөрчлөгдөж, шинэчлэгдээсэй гэж хүсдэг. Гэсэн ч чи өөрт чинь юу сайн болохыг мэддэггүй, үргэлж шинжлэн шалгаж, аль эсвэл нягтлан үзэж байдаг. Бурхан чамд хүндрэл учруулаад байгаа юм биш, харин чи Бурханыг огт хүндэлдэггүй, мөн дуулгаваргүй байдал чинь дэндүү их. Өчүүхэн жаахан бүтээгдсэн зүйл урьд нь Бурханы өгсөн зүйлийн ялимгүй бага хэсгийг авч зүрхэлдэг, дараа нь эргээд үүнийгээ ашиглан Бурхан руу дайрч давшилдаг—энэ нь хүний дуулгаваргүй байдал биш гэж үү? Хүмүүст Бурханы өмнө үзэл бодлоо илэрхийлэх эрх огт байхгүй, тэдгээр хуучинсаг үзэл битгий хэл, үнэ цэнгүй, олиггүй, илжирсэн, уран цэцэн үг хэлээ хүссэнээрээ гайхуулах эрх бүр ч байхгүй гэж хэлж болно. Тэдгээр нь бүр ч үнэ цэнгүй бус уу?

Бурханд үнэхээр үйлчилдэг хүн бол Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг, Бурхан ашиглахад тохирсон хүн бөгөөд шашны үзлийг орхиж чаддаг. Хэрвээ чи Бурханы үгийг үр өгөөжтэйгөөр идэж, уухыг хүсвэл шашны үзлээ орхих учиртай. Хэрвээ чи Бурханд үйлчлэхийг хүсдэг бол эхлээд шашны үзлээ орхиж, бүх зүйл дээр Бурханы үгийг дуулгавартай дагах нь бүр ч чухал юм. Бурханд үйлчилдэг хүний эзэмших ёстой зүйл энэ билээ. Хэрвээ чамд ийм мэдлэг байхгүй бол үйлчилж эхэлмэгцээ л саад тотгор, үймээн учруулах ба өөрийн үзлийг баримталсаар байвал Бурхан чамайг хэзээ ч дахин босохооргүй болтол цохин унагах нь гарцаагүй. Жишээлбэл, өнөө үеийг аваад үзье: Өнөөдрийн олон айлдвар болон ажил Библитэй нийцдэггүй, урьд нь Бурханы хийсэн ажилтай таардаггүй бөгөөд хэрвээ чамд дуулгавартай дагах хүсэл байхгүй бол чи хэдийд ч унаж магадгүй. Хэрвээ чи Бурханы хүслийн дагуу үйлчлэхийг хүсэж байвал эхлээд шашны үзлээ орхиж, өөрийн үзэл бодлыг засаж залруулах ёстой. Ирээдүйд хэлэх зүйлсийн ихэнх нь өнгөрсөнд хэлж байсантай нийцэхгүй ба хэрвээ одоо чамд дуулгавартай дагах хүсэл байхгүй бол өмнөх замаараа алхаж чадахгүй. Хэрвээ Бурханы ажилладаг аргуудын нэг нь чиний дотор үндэслэж, чи үүнийг хэзээ ч орхиогүй бол тэр арга чиний шашны үзэл болно. Хэрвээ Бурхан юу болох нь дотор чинь үндэслэсэн бол чи үнэнийг олж авсан бөгөөд Бурханы үг болон үнэн амь чинь болж чаддаг бол Бурханы талаар үзэлтэй байхаа болино. Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй хүмүүс ямар ч үзэлгүй байх бөгөөд хоосон сургаал баримтлахгүй.

Сонор сэрэмжтэй байхын тулд эдгээр асуултыг асуу:

1. Чамд байгаа мэдлэг Бурханд үйлчлэхэд чинь саад болдог уу?
2. Өдөр тутмын амьдралд чинь хэр олон шашны хэрэгжүүлэлт байдаг вэ? Хэрвээ чи зөвхөн сүсэг бишрэлтэй мэт харагддаг бол амь чинь өсөж, төлөвшсөн гэсэн үг мөн үү?
3. Чи Бурханы үгийг идэж, уух үедээ шашны үзлээ орхиж чаддаг уу?
4. Залбирах үедээ чи шашны зан үйлээс ангижирч чаддаг уу?
5. Чи Бурхан ашиглахад тохирсон хүн мөн үү?
6. Бурханы талаарх мэдлэгийн чинь хэр их нь шашны үзэл агуулдаг вэ?

БУРХАНЫГ ХАЙРЛАХ ЖИНХЭНЭ ХАЙР АЯНДАА ТӨРДӨГ

Бурханы үгээс болж бүх хүн цэвэршүүлэлтийг туулах ёстой болсон. Хэрвээ Бурхан бие махбодтой болоогүй байсан бол хүн төрөлхтөнд мэдээж энэ цэвэршүүлэлтээр дамжуулан зовох ерөөл тохиохгүй байсан юм. Өөрөөр хэлбэл, Бурханы үгийн шалгалтыг хүлээн зөвшөөрч чаддаг бүх хүн ерөөгдсөн юм. Хүмүүсийн төрөлх хэв чанар, зан авир болон Бурханд хандах хандлагаар бол хүмүүс ийм цэвэршүүлэлтийг хүлээн авахад тохирохгүй. Бурхан тэднийг өргөсөн учраас тэд энэ ерөөлийг эдэлсэн юм. Хүмүүс өөрсдийгөө Бурханы царайг харж, Түүний үгийг сонсох эрхгүй гэж хэлдэг байсан. Өнөөдөр гагцхүү Бурханы өргөлт болон Түүний өршөөлөөс болж л хүмүүс Түүний үгийн цэвэршүүлэлтийг хүлээн авсан билээ. Энэ бол эцсийн өдрүүдэд төрсөн хүн нэг бүрийн ерөөл юм—та нар үүнийг биеэрээ туулсан уу? Хүмүүс аль талаараа зовлон зүдүүр, бүтэлгүйтлийг туулах вэ гэдгийг Бурхан урьдаас шийддэг ба энэ нь хүмүүсийн өөрсдийнх нь шаардлагаас шалтгаалдаггүй юм. Энэ бол гарцаагүй үнэн. Итгэгч бүр Бурханы үгийн шалгалтыг хүлээн зөвшөөрч, Түүний үгээр зовох чадвартай байх ёстой. Энэ та нарт ойлгомжтой байна уу? Иймээс туулсан зовлонгийнхоо хариуд чи өнөөдрийн ерөөлийг хүртсэн; хэрвээ чи Бурханы төлөө зовохгүй бол Түүний магтаалыг хүртэж чадахгүй. Урьд нь чи гомдоллодог байсан байж болно, гэхдээ хэчнээн их гомдоллосон ч гэсэн, Бурхан тэр гомдлыг чинь санадаггүй. Өнөөдөр, нэгэнт ирсэн бөгөөд өчигдрийн хэрэг явдлыг судалж шинжлэх хэрэггүй.

Зарим хүн Бурханыг хайрлахыг хичээдэг боловч чадахгүй юм гэж хэлдэг. Харин Бурхан явах гэж байгааг сонсохоороо гэнэтхэн Түүнийг хайрлаж эхэлдэг. Зарим хүн үнэнийг ерөнхийдөө хэрэгжүүлдэггүй бөгөөд Бурхан уурсан явах гэж байгааг сонсоод Түүний өмнө очиж ийнхүү залбирдаг: “Өө Бурхан минь! Битгий яваач. Надад боломж олгооч! Бурхан минь! Би өмнө нь Таныг сэтгэл хангалуун байлгаагүй; би Танд өртэй, би Таныг эсэргүүцсээр ирсэн. Өнөөдөр би, бие сэтгэлээ бүрэн дүүрэн өргөхөд бэлэн байна, ингэж байж л сая нэг юм Таныг сэтгэл хангалуун байлгаж, Таныг хайрлана. Надад ийм боломж дахин ирэхгүй”. Чи ингэж залбирч байсан уу? Хүний мөс чанарыг Бурханы үг өдөөснөөр хүн ингэж залбирдаг. Хүмүүс бүгд хөшүүн, мулгуу байдаг. Тэд гэсгээлт, цэвэршүүлэлтийг туулах ёстой байдаг ч Бурхан үүгээр юуг гүйцэлдүүлэх гэж хичээж байгааг мэддэггүй. Хэрвээ Бурхан ийм маягаар ажиллаагүй бол хүмүүс мунгинасан хэвээр байх байсан; хүмүүсийн зүрх сэтгэл дэх сүнслэг мэдрэмжийг хэн ч өдөөж чадахгүй. Хүмүүсийг шүүж, илчилдэг Бурханы үг л ийм үр дүнг авчирдаг. Иймээс Бурханы үгээс болж бүх зүйл хэрэгжиж, биелдэг бөгөөд Түүний үгээс болж л Бурханыг гэх хүн төрөлхтний хайр өдөөгддөг. Дан ганц хүний мөс чанарт тулгуурласан Бурханыг хайрлах хайр хүссэн үр дүнг авчрахгүй. Урьд нь хүмүүс мөн чанар дээрээ тулгуурлан Бурханыг хайрладаг байгаагүй гэж үү? Өөрийн санаачилгаар Бурханыг хайрласан нэг ч атугай хүн

байсан уу? Хүмүүс Бурханы үгээр урамшсандаа л Бурханыг хайрласан. “Би Бурханыг маш олон жил дагаж, Түүний нигүүлсэл, ерөөлийг маш их эдэлсэн. Би Түүний үгээс цэвэршүүлэлт, шүүлтийг туулах ёстой болсон. Тэгээд Би ихийг ойлгож авч, Бурханы хайрыг харсан. Би Түүнд талархах ёстой, Түүний нигүүлслийг хариулах ёстой. Би үхлээр Бурханыг сэтгэл хангалуун болгох болно, мөн Түүнийг гэсэн хайраа мөс чанартаа тулгуурлах болно” гэж зарим хүн хэлдэг. Хэрвээ хүмүүс мөс чанарынхаа мэдрэмжид л найддаг бол Бурханы хайр татам байдлыг мэдэрч чадахгүй. Зөвхөн мөс чанартаа найддаг бол Бурханыг гэх тэдний хайр мөхөсхөн байх болно. Хэрвээ чи Бурханы нигүүлсэл, хайрыг хариулах талаар л ярьдаг бол Түүнийг гэх хайр чинь ямар ч урам зориггүй байх болно; мөс чанарынхаа мэдрэмжид тулгуурлан Түүнийг хайрлах нь идэвхгүй хандлага юм. Яагаад Би үүнийг идэвхгүй хандлага гэж хэлж байна вэ? Энэ бол бодит асуудал. Бурханыг гэх хайр чинь ямар хайр вэ? Ердөө л Бурханыг хуурч, Түүний төлөө хэлбэр төдий үйлдэж байдаг бус уу? Ихэнх хүн, Бурханыг хайрласны төлөө ямар ч шагнал байхгүй, Түүнийг хайрладаггүй байлаа гээд хүн яг л ижилхэн гэсгээгдэх болохоор ерөнхийдөө нүгэл үйлдэхгүй байхад л хангалттай гэж итгэдэг. Тэгэхээр мөс чанарынхаа мэдрэмжид тулгуурлан Бурханыг хайрлаж, Түүний хайрыг хариулах нь идэвхгүй хандлага бөгөөд хүний зүрх сэтгэлээс аяндаа гардаг Бурханыг гэх хайр энэ биш юм. Бурханыг гэх хайр бол хүний зүрх сэтгэлийн гүнээс гардаг жинхэнэ мэдрэмж байх ёстой. “Би өөрөө Бурханыг эрж хайж, Түүнийг дагахад бэлэн байна. Одоо Бурхан намайг орхихыг хүссэн ч би Түүнийг дагасаар байх болно. Тэр намайг хүсдэг ч бай, үгүй ч бай би Түүнийг хайрласаар байх болно, тэгээд эцэст нь би Түүнийг олж авах ёстой. Би Бурханд зүрх сэтгэлээ өргөдөг, Тэр юу ч хийсэн бай, би Түүнийг насан туршдаа дагана. Юу ч болсон бай хамаагүй, би Бурханыг хайрлаж, Түүнийг олж авах ёстой; Түүнийг олж авах хүртлээ би амрахгүй” гэж зарим хүн хэлдэг. Чамд ийм шийдэмгий зан байгаа юу?

Бурханд итгэх зам болон Түүнийг хайрлах зам хоёр нь нэг л зүйл юм. Хэрвээ чи Түүнд итгэдэг бол Түүнийг хайрлах ёстой; гэхдээ Түүнийг хайрлах гэдэг нь зөвхөн Түүний хайрыг хариулахыг, эсвэл мөс чанарынхаа мэдрэмжид тулгуурлан Түүнийг хайрлахыг хэлдэггүй—энэ бол Бурханыг гэх цэвэр ариун хайр юм. Зарим үед хүмүүс дан ганц мөс чанартаа тулгуурлаад Бурханы хайрыг мэдэрч чаддаггүй. Би яагаад үргэлж “Бурханы Сүнс бидний сүнсийг хөдөлгөх болтугай” гэж хэлдэг вэ? Бурханыг хайрлахын тулд хүмүүсийн мөс чанарыг хөдөлгөх тухай Би яагаад яриагүй вэ? Яагаад гэвэл хүмүүсийн мөс чанар Бурханы хайр татам байдлыг мэдэрч чаддаггүй. Хэрвээ чи эдгээр үгэнд үнэмшихгүй байгаа бол мөс чанараа ашиглан Түүний хайрыг мэдрэх гээд үзээрэй. Чамд тухайн үедээ урам зориг орж магадгүй боловч удалгүй алга болно. Хэрвээ чи зөвхөн мөс чанарааараа Бурханы хайр татам байдлыг мэдэрдэг бол залбирах үедээ урам зориг авах боловч удалгүй урам зориг чинь бөхөж, алга болно. Яагаад тэр вэ? Хэрвээ чи мөс чанараа л ашиглавал Бурханыг гэх хайраа өдөөж чадахгүй; чи зүрх сэтгэлээрээ Түүний хайр

татам байдлыг үнэхээр мэдрэх үед сүнсийг чинь Тэр хөдөлгөх бөгөөд тэр үед л мөс чанар чинь анхдагч үүргээ гүйцэтгэх чадвартай болно. Өөрөөр хэлбэл, Бурхан хүний сүнсийг хөдөлгөх үед, хүн мэдлэгтэй, зүрх сэтгэлдээ урам зоригтой байх үед, нэг үгээр хэлбэл хүн туршлага олж авсан үедээ л мөс чанарааараа Бурханыг амжилттай хайрлаж чадна. Мөс чанарааараа Бурханыг хайрлах нь буруу зүйл биш—энэ бол Бурханыг хайрлах хамгийн доод шат юм. “Бурханы нигүүлслийг зүй ёсоор хариулах төдий л” хайрлах нь хүнд идэвхтэйгээр орох түлхэц ердөө өгөхгүй. Хүмүүс Ариун Сүнсний зарим ажлыг олж авах үед, өөрөөр хэлбэл, бодит туршлагаараа Бурханы хайрыг харж, мэдрэх үед, Бурханы талаар бага зэрэг мэдлэгтэй болж, хүн төрөлхтөн үнэхээр Бурханыг хайрлууштай, Тэр хэчнээн хайр татам болохыг жинхэнээсээ харах үедээ л Бурханыг чин сэтгэлээсээ хайрлаж чаддаг.

Хүмүүс Бурхантай зүрх сэтгэлээрээ холбогдож, зүрх сэтгэлээ Түүн рүү бүрэн эргүүлж чаддаг болох үе бол Бурханыг гэх хүний хайрын эхний алхам юм. Бурханыг хайрлахыг хүсдэг бол эхлээд зүрх сэтгэлээ Түүн рүү эргүүлж чаддаг байх ёстой. Зүрх сэтгэлээ Бурхан руу эргүүлэх гэж юу вэ? Энэ нь зүрх сэтгэлдээ эрэлхийлдэг бүхэн чинь Бурханыг хайрлаж, олж авахын төлөө байх тэр үе юм. Зүрх сэтгэлээ Бурхан руу бүрэн эргүүлсэн гэдгийг чинь энэ харуулдаг. Зүрх сэтгэлд чинь Бурхан болон Түүний үгээс өөр бараг юу ч (гэр бүл, эд хөрөнгө, эхнэр, нөхөр, үр хүүхэд гэх мэт) байхгүй. Байлаа ч гэсэн тийм зүйлс зүрх сэтгэлийг чинь эзэмдэж чадахгүй бөгөөд чи хэтийн ирээдүйгээ бодох бус, харин зөвхөн Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг. Тийм л үед чи зүрх сэтгэлээ Бурхан руу бүрэн эргүүлсэн байх болно. Чи зүрх сэтгэлдээ өөртөө зориулсан төлөвлөгөөг гаргасаар л, үргэлж өөрийн хувийн ашиг хонжоог хөөж: “Би хэзээ Бурханаас жаахан зүйл хүсэж болох бол? Гэр бүл минь хэзээ чинээлэг болох вэ? Би яаж хэдэн аятайхан хувцастай болох вэ? …” хэмээн үргэлж боддог гэж үзье. Хэрвээ чи ийм байдалд амьдарч байгаа бол зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрэн эргээгүй байгааг энэ нь харуулдаг. Чи зүрх сэтгэлдээ зөвхөн Бурханы үгийг тээж, яг л Бурхан чамд маш ойр байгаа мэт, яг л Тэр чиний дотор, чи Түүний дотор байгаа мэт хэзээд ч Бурханд залбирч, ойр байдаг болсон бол, хэрэв чи ийм төлөв байдалд байгаа бол зүрх сэтгэл чинь Бурханы өмнө байна гэсэн үг юм. Чи Бурханд залбирч, Түүний үгийг өдөр бүр идэж, уудаг, мөн чуулганы ажлыг байнга боддог, Бурханы хүсэлд анхаарал тавьж, Түүнийг жинхэнээсээ, сэтгэлээсээ хайрлаж, Түүний зүрх сэтгэлийг хангалуун болгодог бол зүрх сэтгэл чинь Бурханд харьяалагдана. Хэрвээ зүрх сэтгэлийг чинь өөр олон зүйл эзэмддэг бол Сатанд эзэмдүүлсэн хэвээр л байгаа бөгөөд Бурхан руу үнэхээр эргээгүй байна. Хүний зүрх сэтгэл Бурхан руу үнэхээр эргэсэн бол Бурханыг чин сэтгэлээсээ, аяндаа хайрлаж, Түүний ажлыг анхаарч чаддаг болдог. Тэдэнд мунхаглаж, эрүүл ухаангүй загнах үе гарсаар байх хэдий ч тэд Бурханы гэрийн ашиг сонирхол, Түүний ажил болон өөрсдийн зан чанарын өөрчлөлтөд анхаарал тавьдаг бөгөөд сайхан сэтгэл өвөрлөж явдаг юм. Зарим хүн юм болгоныг чуулганы төлөө хийдэг гэдэг боловч үнэн хэрэгтээ өөрсдийнхөө ашиг тусын төлөө ажиллаж

байдаг. Ийм хүмүүс буруу санаа зорилготой юм. Тэд бол шударга бус, ов мэхтэй бөгөөд хийдэг ихэнх зүйл нь хувийн ашиг хонжооны төлөө байдаг. Ийм хүн Бурханыг хайрлахаар эрэлхийлдэггүй; зүрх сэтгэл нь Сатанд харьяалагдсан хэвээр байж, Бурхан руу эргэж чаддаггүй. Тиймээс Бурхан ийм хүнийг олж авах ямар ч аргагүй.

Бурханыг үнэхээр хайрлаж, Түүгээр авхуулахыг хүсдэг бол эхний алхам нь зүрх сэтгэлээ Бурханы руу бүрмөсөн эргүүлэх юм. Хийдэг юм бүхэн дээрээ өөрийгөө шинжилж, ингэж асуу: “Би үүнийг Бурханыг хайрлах сэтгэлээр хийж байна уу? Үүний ард ямар нэгэн хувийн санаа зорилго байгаа юу? Үүнийг хийж байгаагийн минь жинхэнэ зорилго юу вэ?” Хэрвээ чи зүрх сэтгэлээ Бурханд өгөхийг хүсэж байгаа бол эхлээд зүрх сэтгэлээ захирч, хувийн бүх санаа зорилгоо орхиж, тэр чигээрээ Бурханы төлөө байх байдалд хүрэх ёстой. Энэ бол Бурханд зүрх сэтгэлээ өгч дадах зам юм. Зүрх сэтгэлээ захирна гэж юуг хэлдэг вэ? Энэ бол махан биеийн хэрээс хэтэрсэн хүслээ орхиж, байр суурийн ашиг тус, тав тухад шунахгүй байж, Бурханыг хангалуун байлгахын төлөө бүхнийг хийж, зүрх сэтгэлээ өөрийнхөө төлөө биш, бүрмөсөн Түүний төлөө болгох юм. Энэ л хангалттай.

Бурханыг хайрлах жинхэнэ хайр зүрх сэтгэлийн гүнээс гардаг; энэ бол Бурханы талаарх хүний мэдлэгийн үндсэн дээр л оршдог хайр юм. Хүний зүрх сэтгэл Бурхан руу бүрмөсөн эргэх үед тэд Бурханыг хайрладаг болдог ч тэрхүү хайр нь заавал цэвэр ариун, заавал бүрэн дүүрэн байх албагүй. Учир нь хүний зүрх сэтгэл Бурхан руу бүрмөсөн эргэх болон тухайн хүн Бурханыг жинхэнээсээ ойлгож, жинхэнээсээ бишрэн шүтэхийн хооронд бас л тодорхой зай байсаар байдаг. Бурханыг жинхэнээсээ хайрладаг болж, Бурханы зан чанарыг мэдэж авах зам бол Бурхан руу зүрх сэтгэлээ эргүүлэх явдал юм. Үнэн зүрх сэтгэлээ Бурханд өгснийхөө дараа хүн амийн туршлага руу орж эхлэх ба ийм маягаар түүний зан чанар өөрчлөгдөж эхлэн, Бурханыг гэх хайр нь аажмаар өсөж, Бурханы талаарх мэдлэг нь ч бас аажмаар нэмэгддэг. Тэгэхээр зүрх сэтгэлээ Бурхан руу эргүүлэх нь амийн туршлагын зөв замд орох зөвхөн урьдчилсан нөхцөл юм. Хүмүүс зүрх сэтгэлээ Бурханы өмнө тавихдаа зүрх сэтгэлдээ Түүнийг хүсэмжилж байдаг болохоос биш, хайрлаж байдаггүй, учир нь тэд Түүнийг ойлгодоггүй. Ийм нөхцөлд Түүнийг гэх тодорхой хэмжээний хайр тэдэнд байдаг ч энэ нь аяндаа төрдөггүй, бас жинхэнэ бус юм. Яагаад гэвэл хүний махан биеэс гардаг бүхэн сэтгэл хөдлөлийн үр дагавар бөгөөд жинхэнэ ойлголтоос гардаггүй. Энэ бол ердөө л түр зуурын сэтгэл хөдлөл бөгөөд удаан хугацааны хүндлэл бишрэл болж чаддаггүй. Хүмүүс Бурханы талаар ойлголтгүй байх үедээ эрхэмлэдэг зүйл болон хувийн үзэлдээ л тулгуурлан Түүнийг хайрлаж чаддаг; тийм хайрыг аяндаа төрдөг хайр гэж хэлж болохгүй, жинхэнэ хайр ч гэж хэлж болохгүй. Хүний зүрх сэтгэл үнэхээр Бурхан руу эргэж, бүх зүйл дээр Бурханы ашиг сонирхлыг бодож чаддаг боллоо ч гэсэн Бурханы талаар ямар ч ойлголтгүй байх юм бол чин сэтгэлээсээ аяндаа хайрлах чадваргүй байх болно. Түүний хийж чадах зүйл нь чуулганы төлөө зарим нэг чиг үүрэг биелүүлж, үүргээ багахан гүйцэтгэх л

байх боловч үүнийгээ ямар ч суурьгүйгээр хийнэ. Ийм хүний зан чанарыг өөрчлөхөд хэцүү байдаг; ийм хүмүүс нэг бол үнэнийг эрэлхийлдэггүй, эсвэл ойлгодоггүй. Хүн зүрх сэтгэлээ Бурхан руу бүрмөсөн эргүүлсэн ч гэсэн, Бурханыг хайрладаг зүрх сэтгэл нь цэвэр ариухан гэсэн үг биш, учир нь зүрх сэтгэлд нь Бурхан байлаа гээд зүрх сэтгэлд нь Бурханыг гэх хайр байх заавал албагүй. Энэ нь Бурханыг ойлгохоор эрэлхийлдэг болон эрэлхийлдэггүй хүмүүсийн хоорондох ялгаатай холбоотой. Хүн Бурханы талаар ойлголттой болсон бол тэдний зүрх сэтгэл Бурхан руу бүрмөсөн эргэсэн бөгөөд Бурханыг гэсэн жинхэнэ хайр зүрх сэтгэлд нь аяндаа төрдөг гэдгийг энэ нь харуулж байна. Ийм хүмүүсийн л зүрх сэтгэлд Бурхан байдаг. Зүрх сэтгэлээ Бурхан руу эргүүлэх нь зөв замд орж, Бурханыг ойлгож, Бурханыг хайрладаг болохын урьдчилсан нөхцөл юм. Энэ бол Бурханыг хайрлах үүргээ биелүүлсний тэмдэг биш, Түүнийг жинхэнээсээ хайрладгийн тэмдэг ч биш. Хүн Бурханыг жинхэнээсээ хайрладаг болох цорын ганц арга зам нь зүрх сэтгэлээ Түүн рүү эргүүлэх явдал бөгөөд энэ нь бас Түүний бүтээлүүдийн нэг болохынхоо хувьд хийх учиртай эхний зүйл нь мөн. Бурханыг хайрладаг хүмүүс бол бүгдээрээ амийг эрэлхийлдэг хүн юм, өөрөөр хэлбэл, үнэнийг эрэлхийлдэг, Бурханыг үнэхээр хүсдэг хүмүүс юм; тэд бүгдээрээ Ариун Сүнсний гэгээрлийг хүртсэн байдаг бөгөөд Тэр тэдний сэтгэлийг хөдөлгөсөн. Тэд бүгд Бурханаар замчлуулж чаддаг.

Хүн Бурханд өртэй гэдгээ мэдрэх чадвартай болно гэдэг нь тэдний сэтгэлийг Сүнс хөдөлгөснөөс тэр юм; ингэж мэдэрдэг хүмүүс ер нь л зүрх сэтгэлдээ эрмэлзэлтэй байдаг бөгөөд амийн оролтыг эрэлхийлж чадна. Харин чи тодорхой алхам дээр зогсвол илүү гүн орж чадахгүй; Сатаны торонд гацах аюул байсаар байгаа ба хэзээ нэгэн цагт Сатан чамайг олзолно. Бурханы гэрэлтүүлэлт хүмүүст өөрсдийг нь мэдүүлж, дараа нь Бурханд өртэйг нь мэдрүүлдэг; тэд Түүнтэй хамтран ажиллаж, Түүний таалалд нийцэхгүй зүйлсийг хөсөр хаяхад бэлэн болдог. Энэ бол Бурханы ажлын зарчим юм. Та нар бүгд амиа өсгөж, Бурханыг хайрлахаар эрэлхийлэх хүсэлтэй байгаа, тэгвэл чи өнгөц дадлуудаасаа салсан уу? Чи зөвхөн өнгөц дадлуудаасаа салж, саад учруулдаг, сайрхуу зан авирыг тэвчдэг бол энэ нь амийн өсөлтийг эрэлхийлж байгаа хэрэг мөн гэж үү? Хэрэв чи гадаад өнгөц зан авираас салсан боловч Бурханы үг рүү ордоггүй бол ахиц дэвшил идэвхтэй гаргахгүй байгааг чинь энэ нь харуулдаг. Гадаад өнгөц зан авирын уг үндэс юу вэ? Үйлдэл чинь амиа өсгөхийн төлөө байдаг уу? Чи Бурханы ардуудын нэг гэж хүлээн зөвшөөрөгдөхөөр эрж хайдаг уу? Анхаарлаа төвлөрүүлдэг бүхэн чинь чиний амьдран харуулдаг зүйл юм; хэрвээ чи өнгөц зан авирт анхаарлаа төвлөрүүлдэг бол зүрх сэтгэл чинь байнга гадагш чиглэж, амийн өсөлтийг эрэлхийлэх аргагүй болно. Бурхан зан чанарын өөрчлөлтийг шаарддаг боловч чи үргэлж гадаад зүйлсийг эрэлхийлж байдаг; ийм хүн зан чанараа өөрчлөх чадваргүй байдаг! Амийн төлөвшилд хүрэх явцад хүн бүр нэг замыг дагах ёстой байдаг бөгөөд тэд Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, төгс болголтыг хүлээн зөвшөөрөх ёстой. Чамд Бурханы үг

байдаггүй боловч зөвхөн өөртөө итгэх итгэл болон хүсэл эрмэлзэлдээ найддаг бол хийж байгаа юм бүхэн чинь зөвхөн хичээл зүтгэлд л тулгуурлаж байдаг. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи амийн өсөлтийг хүсдэг бол Бурханы үгийг илүү ихээр идэж ууж, ойлгох ёстой. Түүний үгээр төгс болгуулдаг хэн бүхэн тэдгээрийг амьдран харуулж чаддаг; Түүний үгийн цэвэршүүлэлтийг туулдаггүй, Түүний үгийн шүүлтийг туулдаггүй хүмүүс Түүнд ашиглагдахад тэнцэж чадахгүй. Тэгэхээр та нар Түүний үгийг ямар хэмжээнд амьдран харуулдаг вэ? Та нар Бурханы үгийг идэж уун, түүнийгээ өөрийн амийн байдалтай харьцуулж чаддаг бөгөөд Миний хөндсөн асуудлууд дээр хэрэгжүүлэлтийн замыг олдог байх юм бол л хэрэгжүүлэлт чинь зөв болж, Бурханы хүсэлд нийцэх болно. Ийм хэрэгжүүлэлттэй хүн л Бурханыг хайрлах хүсэлтэй байдаг.

ЗАЛБИРЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Та нар өдөр тутмын амьдралдаа залбиралд ач холбогдол өгдөггүй. Хүн залбирлын асуудлыг үл ойшоодог. Залбирал хааш яаш байж, хүн Бурханы өмнө зүгээр л хийсэн дүр үзүүлдэг байсан. Хэн ч зүрх сэтгэлээ Бурханы өмнө бүрэн өгч, Бурханд үнэхээр залбирч байгаагүй. Хүн асуудал үүсэх үед л Бурханд залбирдаг. Энэ бүх хугацаанд чи ер нь Бурханд үнэхээр залбирсан уу? Бурханы өмнө шаналлын нулимс урсгаж байсан удаа ер нь бий юу? Бурханы өмнө өөрийгөө ер нь мэдэж авч байсан уу? Бурханд зүрх сэтгэлээсээ залбирч үзсэн үү? Залбирал хэрэгжүүлэлтээс бий болдог: Хэрвээ чи гэртээ ер нь залбирдаггүй бол чуулганд залбирах ямар ч аргагүй байх бөгөөд ерөнхийдөө жижиг цуглааны үеэр залбирдаггүй бол том цуглааны үеэр залбирч чадахгүй. Чи ерөнхийдөө Бурханд ойртдоггүй, Бурханы үгийг эргэцүүлдэггүй бол залбирах цаг болоход чамд хэлэх үг олдохгүй ба залбирсан ч гэсэн чи зүгээр л дүр үзүүлж байх болно; тэр нь жинхэнэ залбирал биш юм.

Жинхэнэ залбирал гэж юу вэ? Энэ нь зүрх сэтгэл доторх үгээ Бурханд хэлж, Бурханы хүслийг ухаарснаар Бурхантай ярьж, үгэнд нь үндэслэн Бурхантай ярилцан, Бурханд нэн ойр байгаагаа мэдэрч, Тэр өмнө чинь байгааг мэдэрч, Түүнд хэлэх зүйл бий гэж бодох явдал юм. Зүрх сэтгэл чинь гэрлээр дүүрч, Бурхан хэчнээн хайр татам болохыг мэдэрнэ. Чи тун их зоригжиж, үгийг чинь сонсоход ах эгч нарт таатай санагдана. Хэлсэн үг чинь тэдний зүрх сэтгэл доторх үг, тэдний хэлэхийг хүсдэг үг, мөн тэдний үгийг орлуулагч мэт санагдана. Жинхэнэ залбирал гэж энэ юм. Үнэхээр залбирсны дараа зүрх сэтгэлд чинь амар амгалан болж, баяр баясалтай санагдана. Бурханыг хайрлах хүч чадал нэмэгдэж, амьдралдаа Бурханыг хайрлахаас илүү үнэ цэнтэй, ач холбогдолтой юу ч байхгүй гэж санагдана. Залбирал чинь үр дүнтэй байсныг энэ бүхэн нотолдог. Чи ер нь ийм маягаар залбирч байсан уу?

Тэгвэл залбирлын агуулга юу вэ? Чиний залбирал алхам алхмаар, зүрх сэтгэлийн чинь жинхэнэ байр байдал, Ариун Сүнсний ажлын дагуу байх ёстой; мөн Бурханы хүсэл болон хүнээс шаарддаг шаардлагад нийцүүлэн Бурхантай ярилцах ёстой. Чи залбирлаа хэрэгжүүлж эхлэх үедээ эхлээд зүрх сэтгэлээ Бурханд өг. Бурханы хүслийг ухаарахаар бүү оролд, харин зүрх сэтгэл доторх үгээ Бурханд хэлэх гэж л хичээ. Бурханы өмнө очих үедээ ингэж хэл: “Өө Бурхан минь! Танд би дуулгаваргүй байдаг байснаа өнөөдөр л ухаарлаа. Би үнэхээр завхарсан бөгөөд жигшүүртэй. Би амьдралаа хий дэмий өнгөрөөсөөр иржээ. Өнөөдрөөс эхлээд би Таны төлөө амьдарна. Би утга учиртай амьдралыг амьдран харуулж, Таны хүслийг хангалуун байлгана. Таны Сүнс үргэлж миний дотор ажиллаж, намайг үргэлж гэрэлтүүлж, гэгээрүүлэх болтугай. Би Таны өмнө хүчтэй, цангинасан гэрчлэл хийе. Биднээс харагддаг Таны алдар, Таны гэрчлэл, Таны ялалтын баталгааг Сатанд хараг.” Ийм маягаар залбирах үед зүрх сэтгэл чинь бүрмөсөн чөлөөлөгдөнө. Ийм маягаар залбирснаар зүрх сэтгэл чинь Бурханд илүү ойртоно, ийм маягаар байнга залбирч чадвал Ариун Сүнс чиний дотор гарцаагүй ажиллана. Чи үргэлж ийм маягаар Бурханыг дуудаж, Бурханы өмнө шийдвэрээ гаргадаг бол Бурхан шийдвэрийг чинь хүлээн зөвшөөрч, зүрх сэтгэл болон бүхий л оршихуйг чинь олж авах өдөр ирж, эцэст нь чи Бурханаар төгс болгуулна. Залбирал та нарын хувьд дээд зэргийн ач холбогдолтой юм. Залбирах үедээ чи Ариун Сүнсний ажлыг хүлээн авч, зүрх сэтгэл чинь Бурханаар хөдөлгөгдөж, Бурханыг хайрлах хүч гарч ирдэг. Чи чин сэтгэлээсээ залбирдаггүй, Бурхантай ярилцахын тулд зүрх сэтгэлээ нээдэггүй бол Бурхан чиний дотор ажиллах ямар ч аргагүй байх болно. Чи залбирч, зүрх сэтгэл доторх бүх үгээ хэлсний дараа Бурханы Сүнс ажлаа эхлээгүй, мөн чи ямар ч урам зориг аваагүй бол зүрх сэтгэл чинь чин үнэнч биш, үг чинь үнэн биш, хольцтой хэвээр гэдгийг энэ нь харуулдаг. Залбирчхаад сэтгэл чинь ханамжтай байвал залбирлыг чинь Бурхан хүлээн зөвшөөрч, Бурханы Сүнс чиний дотор ажиллаж байна. Бурханы өмнө үйлчилдэг нэгэн болохын хувьд чи залбирахгүй байж болохгүй. Чи Бурхантай хийх нөхөрлөлийг үнэхээр л утга учиртай, үнэ цэнтэй гэж үздэг бол залбирлыг орхиж чадна гэж үү? Бурхантай ярилцахгүй байж хэн ч чадахгүй. Залбиралгүйгээр чи махан биед, Сатаны хүлээсэнд амьдардаг; жинхэнэ залбиралгүйгээр чи харанхуйн нөлөөн дор амьдардаг. Ах эгч та нар өдөр болгон үнэхээр залбирч чадна гэж Би найдаж байна. Энэ нь ёс заншил сахих явдал бус, тодорхой үр дүнд хүрэх явдал юм. Чи жаахан нойр, зугаа цэнгэлээс татгалзан, үүрээр өглөөний залбирлаа хийж, дараа нь Бурханы үгийг эдлэхэд бэлэн байна уу? Хэрвээ чи энэ маягаар ариун зүрх сэтгэлээр залбирч, Бурханы үгийг идэж, уудаг бол чамайг Бурхан улам илүү хүлээн зөвшөөрнө. Өглөө бүр үүнийг хийж, өдөр бүр зүрх сэтгэлээ Бурханд өгч, Бурхантай ярилцаж, харилцвал Бурханы талаарх мэдлэг чинь гарцаагүй ихсэж, Бурханы хүслийг илүү сайн ухаарч чадна. Чи ингэж хэлнэ: “Өө Бурхан минь! Би үүргээ биелүүлмээр байна. Та биднээс алдрыг олж авч, энэ бүлэг хүмүүс бидний хийсэн гэрчлэлийг эдлэг гэсэндээ би бүх оршихуйгаа Танд

зориулж л чадна. Бидний дотор ажиллаач гэж би Танаас гуйя, ингэснээр би Таныг үнэхээр хайрлаж, сэтгэл хангалуун байлгаж, Таныг эрэлхийлдэг зорилгоо болгож чадна.” Энэ ачааг үүрэх үед чинь Бурхан чамайг гарцаагүй төгс болгоно. Чи зөвхөн өөрийнхөө төлөө залбиралгүй, харин Бурханы хүслийг биелүүлэх, Түүнийг хайрлахын төлөө бас залбирах ёстой. Энэ нь хамгийн жинхэнэ залбирал юм. Чи Бурханы хүслийг биелүүлэхийн төлөө залбирдаг хүн мөн үү?

Өмнө нь та нар хэрхэн залбирахаа мэддэггүй, залбирлыг үл ойшоодог байсан. Одоо та нар залбирч сурахын тулд чадах бүхнээ хийх ёстой. Бурханыг хайрлахын тулд доторх хүчээ дайчилж чадахгүй бол чи яаж залбирч чадах юм бэ? Чи ингэж хэлэх ёстой: “Өө Бурхан минь! Зүрх сэтгэл минь Таныг үнэхээр хайрлах чадваргүй. Би Таныг хайрлахыг хүсдэг ч надад хүч дутдаг. Би яах ёстой вэ? Та сүнсний минь нүдийг нээж, Таны Сүнс миний зүрх сэтгэлийг хөдөлгөх болтугай. Ингэснээр би Таны өмнө бүх сөрөг зүйлийг хаяж, аливаа хүн, хэрэг явдал, зүйлээр хязгаарлагдахгүй байж, бүхий л оршихуйгаа Таны өмнө зориулахуйцаар зүрх сэтгэлээ Таны өмнө бүрэн дэлгэж байна. Та намайг яаж ч туршсан бай, би бэлэн. Одоо би хэтийн ирээдүйгээ огт бодохгүй, мөн үхэлд ч хүлэгдэхгүй. Таныг хайрладаг зүрх сэтгэлээр би амьдралын замыг эрж хайхыг хүсэж байна. Бүх зүйл болон хэрэг явдал болгон Таны гарт байдаг; миний хувь заяа Таны гарт байдаг, амьдрал минь Таны гарт байдаг. Одоо би Таныг хайрлахаар эрэлхийлдэг, Та надаар хайрлуулах эсэхээс үл хамааран, Сатан хэрхэн саад болохоос үл хамааран Таныг хайрлахаар шийдсэн.” Ийм асуудалтай тулгарах үедээ ингэж залбир. Хэрвээ чи өдөр болгон ингэж залбирвал Бурханыг хайрлах хүч аажмаар нэмэгдэнэ.

Хүн жинхэнэ залбиралд хэрхэн орох вэ?

Залбирах үедээ чи Бурханы өмнө тайван зүрх сэтгэлтэй байж, чин үнэнч сэтгэлтэй байх ёстой. Чи үнэхээр Бурхантай ярилцан, залбирч байгаа—чи чихэнд чимэгтэй үгээр Бурханыг аргалах ёсгүй. Бурханы яг одоо гүйцэлдүүлэхийг хүсдэг зүйл дээр залбирал төвлөрөх ёстой. Чамд илүү их гэгээрэл, гэрэлтүүлэлт өгөхийг Бурханаас гуй, залбирахдаа өөрийн бодит байдал, бэрхшээл болон Бурханы өмнө гаргасан шийдвэрээ Түүний өмнө авчир. Залбирал бол дэг журмыг дагах явдал биш; энэ нь чин зүрх сэтгэлээр Бурханыг эрж хайх явдал юм. Зүрх сэтгэлээ Бурханы өмнө байнга тайван байлгахын тулд зүрх сэтгэлийг чинь хамгаалахыг Бурханаас гуй; Бурханы чамд зориулсан орчинд өөрийгөө мэдэж, жигшиж, хаядаг болж, улмаар Бурхантай хэвийн харилцаатай, Бурханыг үнэхээр хайрладаг хүн болгооч гэж Бурханаас гуй.

Залбирлын ач холбогдол юу вэ?

Залбирал бол хүний Бурхантай хамтран ажилладаг арга замуудын нэг. Энэ нь Бурханыг дууддаг хүний арга, мөн Бурханы Сүнс хүний сэтгэлийг хөдөлгөдөг үйл явц юм. Залбиралгүй хүмүүс бол сүнсгүй үхдэлүүд бөгөөд тэдэнд Бурханаар хөдөлгөгдөх эрхтэн байхгүйн нотолгоо гэж хэлж болно. Залбиралгүйгээр хэвийн сүнслэг амьдралаар амьдрах боломжгүй, Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлэх

бүр ч боломжгүй. Залбиралгүй байх нь хүний Бурхантай харилцах харилцааг тасалдаг бөгөөд Бурханы сайшаалыг хүртэх боломжгүй байдаг. Бурханд итгэгчийн хувиар хүн хэдий чинээ их залбирна, Бурхан сэтгэлийг нь төдий чинээ их хөдөлгөж, хүн илүү их шийдвэртэй болж, Бурханаас шинэ гэгээрлийг илүү сайн хүлээн авч чаддаг. Үүний үр дүнд ийм хүнийг л Ариун Сүнс маш хурдан төгс болгож чадна.

Залбирлаар хүрэх учиртай үр нөлөө юу вэ?

Хүмүүс залбирлыг хэрэгжүүлж, залбирлын ач холбогдлыг ойлгож чаддаг байж болох ч залбирал үр нөлөөтэй байна гэдэг нь энгийн хэрэг биш. Залбирал бол хэлбэрдэж, горим журам дагаж, эсвэл Бурханы үгийг цээжээр унших явдал биш. Өөрөөр хэлбэл, залбирах нь тодорхой хэдэн үгийг тоть шиг давтаж, бусдыг дуурайх явдал биш. Бурханаар хөдөлгүүлэхийн тулд чи залбирлаар зүрх сэтгэлээ Бурханд өгч, зүрх сэтгэлээ Бурханд нээж чаддаг байдалд хүрэх ёстой. Залбирлаа үр нөлөөтэй байлгая гэвэл залбирал чинь Бурханы үгийг уншихад үндэслэх ёстой. Бурханы үгэн дотроос залбирснаар л хүн илүү их гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авч чадна. Жинхэнэ залбирлын илрэлүүд нь: Бурханы шаарддаг бүхнийг хүсэн эрмэлздэг зүрх сэтгэлтэй байх, түүнчлэн Түүний шаарддаг зүйлийг гүйцэлдүүлэхийг хүсэж; Бурханы жигшдэг зүйлийг жигшиж, үүний үндсэн дээр энэ талаар бага зэрэг ойлголттой болж, Бурханы тайлбарласан үнэний талаар мэдэж, тодорхой ойлгох явдал юм. Залбирсны дараа шийдвэр, итгэл, мэдлэг болон хэрэгжүүлэлтийн замтай байхыг л жинхэнэ залбирал гэж нэрлэж болох бөгөөд ийм төрлийн залбирал л үр нөлөөтэй байж чадна. Гэсэн ч залбирал нь Бурханы үгийг эдэлж, үгээр нь Бурхантай ярилцах суурин дээр үндэслэх ёстой ба зүрх сэтгэл чинь Бурханыг эрж хайн, Бурханы өмнө тайван болж чаддаг байх ёстой. Иймэрхүү залбирал Бурхантай үнэхээр ярилцах үе шатанд аль хэдийн орсон байдаг.

Залбирлын тухай хамгийн үндсэн мэдлэг:

1. Санаандаа орсон юуг ч бодлогогүйгээр бүү хэл. Зүрх сэтгэлд чинь ачаа байх ёстой, өөрөөр хэлбэл, залбирах үедээ чи зорилготой байх ёстой.
2. Залбирал Бурханы үгийг агуулах ёстой; энэ нь Бурханы үгэн дээр үндэслэх ёстой.
3. Залбирах үедээ чи хуучирсан асуудлыг сөхөх ёсгүй. Залбирал чинь Бурханы одоогийн үгтэй холбоотой байж, залбирах үедээ сэтгэлийнхээ гүн дэх бодлыг Бурханд хэлэх ёстой.
4. Бүлгийн залбирал төв дээр буюу Ариун Сүнсний өнөөгийн ажилд заавал төвлөрөх ёстой.
5. Бүх хүн бусдын төлөө залбирч сурах ёстой. Энэ нь Бурханы хүслийг анхаардгаа харуулах нэг арга зам юм.

Хувийн залбирлын амьдрал нь залбирлын ач холбогдлын тухай ойлголт болон залбирлын тухай үндсэн мэдлэгт үндэслэдэг. Өдөр тутмын амьдралдаа, дутагдлынхаа төлөө байнга залбирч, амь зан чанартаа өөрчлөлт гаргахын тулд залбирч, Бурханы үгийн тухай мэдлэгтээ үндэслэн залбир. Хүн бүр залбирлын амьдралаа бий болгох

хэрэгтэй, тэд Бурханы үгийг мэдэхийн төлөө залбирч, Бурханы ажлын талаарх мэдлэгийг эрж хайхын тулд залбирах ёстой. Хувийн нөхцөл байдлаа Бурханы өмнө ил болго, залбирдаг арга барилд анхаарал хандуулалгүй бодитой бай, гол асуудал нь жинхэнэ ойлголтод хүрч, Бурханы үгийг бодитоор туулах явдал юм. Сүнслэг амийн оролтыг эрэлхийлдэг хон олон өөр арга замаар залбирч чаддаг байх ёстой. Чимээгүй залбирал, Бурханы үгийг эргэцүүлэх, Бурханы ажлыг мэддэг болох—эдгээр нь бүгд хэвийн сүнслэг амьдралд орохын төлөөх сүнслэг нөхөрлөлийн зоримог ажлын жишээ бөгөөд Бурханы өмнөх байр байдлаа улам сайжруулж, амийн ахиц дэвшлийг бүр ч ихэсгэдэг. Товчхондоо бол Бурханы үгийг идэж, уух ч бай, эсвэл чимээгүй залбирч, чангаар тунхаглах ч бай, хийдэг бүхэн чинь Бурханы үг, ажил болон Түүний чам дээр хэрэгжүүлэхийг хүсдэг зүйлийг тодорхой ойлгохын төлөө байдаг. Бүр ч чухал нь, чиний хийдэг бүхэн Бурханы шаарддаг стандартад хүрч, амиа дараагийн түвшинд аваачихын төлөө байдаг. Хүнээс Бурханы шаарддаг хамгийн наад захын зүйл нь хүн Түүнд зүрх сэтгэлээ нээж чаддаг байх явдал юм. Хүн үнэн сэтгэлээ Бурханд өгч, зүрх сэтгэлд нь үнэхээр байгаа зүйлийг Бурханд хэлдэг бол Бурхан тухайн хүн дээр ажиллах хүсэлтэй байдаг. Бурхан хүний гажуудсан зүрх сэтгэлийг бус, ариун, үнэнч зүрх сэтгэлийг хүсдэг. Хүн Бурхантай үнэн сэтгэлээсээ ярьдаггүй бол Бурхан зүрх сэтгэлийг нь хөдөлгөж, дотор нь ажиллахгүй. Иймээс залбирлын гол чухал зүйл нь Бурхантай үнэн сэтгэлээсээ ярьж, өөрийнхөө дутагдал, тэрслүү зан чанарын талаар хэлж, өөрийгөө Түүний өмнө бүрэн нээх явдал юм; тэр үед л Бурхан залбирлыг чинь сонирхоно, эс бөгөөс Тэр чамаас царайгаа нууна. Залбирлын хамгийн наад захын шалгуур гэвэл чи Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж чаддаг байх ёстой, зүрх сэтгэл чинь Бурханаас холдох ёсгүй. Энэ хугацаанд чи илүү шинэлэг, дээгүүр мэдлэг ухаантай болоогүй байж болох ч байгаа байдлаа хадгалахын тулд залбирлыг ашиглах ёстой—уруудан доройтох ёсгүй. Энэ бол чиний хүрэх ёстой наад захын зүйл. Хэрвээ чи үүнийг ч гүйцэлдүүлж чадахгүй бол сүнслэг амьдрал чинь зөв замд ороогүйг энэ нь нотолно. Улмаар чи анх чамд байсан үзэгдлийг авч үлдэж чадалгүй, Бурханд итгэх итгэлээ алдаж, дараа нь шийдэмгий байдал чинь алга болно. Сүнслэг амьдрал руу орсон эсэхийн чинь нэг тэмдэг бол чиний залбирал зөв замд орсон эсэхийг харах явдал юм. Бүх хүн энэ бодит байдалд орох ёстой; тэд бүгд идэвхгүйгээр хүлээх бус, Ариун Сүнсээр хөдөлгөгдөх гэж ухамсартайгаар эрж хайн, өөрсдийгөө залбиралд ухамсартайгаар сургах ажлыг хийх ёстой. Тэр үед л тэд Бурханыг үнэхээр эрж хайдаг хүмүүс болно.

Залбирч эхлэхдээ чи хэрээс хэтэрч, бүхнийг нэг дор биелүүлэхээр найдах ёсгүй. Чи хэрээс хэтэрсэн шаардлага тавиад, ам нээмэгцээ Ариун Сүнсээр хөдөлгөгдөж, гэгээрэл, гэрэлтүүлэлт хүртэнэ, эсвэл Бурхан чам дээр нигүүлслийг асгана гэж найдаж болохгүй. Ийм явдал тохиолдохгүй; Бурхан ер бусын зүйл хийдэггүй. Бурхан Өөрийнхөө цагт хүмүүсийн залбирлыг биелүүлдэг, мөн Өөрийнх нь өмнө үнэнч эсэхийг чинь харахын тулд заримдаа итгэлийг чинь туршдаг.

Залбирах үедээ чи итгэлтэй, шаргуу, шийдвэртэй байх ёстой. Ихэнх хүн залбирахаар сургуулилж эхлэх үедээ Ариун Сүнсээр хөдөлгөгдөж чаддаггүй учраас хулчийдаг. Ингэж болохгүй! Чи тууштай байх ёстой; Ариун Сүнс сэтгэл хөдөлгөхийг мэдрэхэд болон эрж хайх, судалж шинжлэхэд төвлөрөх ёстой. Заримдаа хэрэгжүүлдэг зам чинь буруу байдаг, заримдаа хувийн сэдэл болон үзэл чинь Бурханы өмнө бат зогсож чаддаггүй тул Бурханы Сүнс чамайг хөдөлгөж чаддаггүй. Зарим үед Бурхан үнэнч үү, үгүй юу гэдгийг чинь хардаг. Товчхондоо гэвэл, чи өөрийгөө сургахад илүү их төлөөс төлөх ёстой. Хэрэгжүүлэлтийн чинь зам гажууд гэдгийг олж мэдвэл чи залбирдаг арга замаа өөрчилж болно. Чи чин сэтгэлээр эрж хайж, хүлээн авахаар хүсэн тэмүүлж байгаа цагт Ариун Сүнс чамайг энэ бодит байдалд аваачих нь лавтай. Заримдаа үнэн зүрх сэтгэлээсээ залбирсан ч чамд төдийлөн сэтгэл хөдөлсөн мэт санагддаггүй. Иймэрхүү үед чи итгэлдээ найдаж, Бурхан залбирлыг чинь хардаг гэж итгэх ёстой; чи залбирахдаа цөхрөлтгүй байх ёстой.

Үнэнч хүн бай; зүрх сэтгэл дэх хууран мэхлэлтээсээ ангижрахын тулд Бурханд залбир. Залбирлаар дамжуулан цаг үргэлж өөрийгөө ариусга, залбирлаар дамжуулан Бурханы Сүнсээр хөдөлгөгд, тэгээд зан чанар чинь аажмаар өөрчлөгдөнө. Жинхэнэ сүнслэг амьдрал бол залбирлын амьдрал юм—энэ нь Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн амьдрал юм. Ариун Сүнсээр хөдөлгөгдөх үйл явц нь хүний зан чанарыг өөрчлөх үйл явц билээ. Ариун Сүнсээр хөдөлгөгдөөгүй амьдрал бол сүнслэг амьдрал бус, харин шашны зан үйлийн л амьдрал юм. Ариун Сүнс байнга сэтгэлийг нь хөдөлгөдөг, мөн Ариун Сүнс гэгээрүүлж, гэрэлтүүлдэг хүмүүс л сүнслэг амьдралд орсон. Хүнийг залбирахад зан чанар нь тасралтгүй өөрчлөгддөг. Бурханы Сүнс түүнийг хэдий чинээ их хөдөлгөнө, тэрээр төдий чинээ идэвх санаачилгатай, дуулгавартай болдог. Иймээс түүний зүрх сэтгэл ч гэсэн аажмаар ариусаж, зан чанар нь алгуурхан өөрчлөгдөнө. Жинхэнэ залбирлын үр нөлөө энэ юм.

БУРХАНЫ ШИНЭХЭН АЖЛЫГ МЭДЭЖ, ТҮҮНИЙ МӨРИЙГ ДАГА

Одоо та нар Бурханы ардууд болохоор эрэлхийлж, бүх зүйл зөв замд орж эхэлнэ. Бурханы ардууд байна гэдэг нь Хаанчлалын эрин үед орно гэсэн үг юм. Өнөөдөр та нар албан ёсоор хаанчлалын сургалтад орж эхэлдэг бөгөөд ирээдүйн амьдрал чинь урьдынх шигээ назгай, хайнга байхаа болино; тийм маягаар амьдарвал Бурханы шаардсан стандартад хүрэх боломжгүй. Хэрвээ чи жаахан ч гэсэн яардаггүй бол чамд өөрийгөө сайжруулах хүсэл байхгүй, чиний эрэл хайгуул будилуу, мунгинуу байгааг энэ нь харуулдаг бөгөөд чи Бурханы хүслийг биелүүлэх чадваргүй. Хаанчлалын сургалтад орох гэдэг нь Бурханы ардын амьдралаар амьдарч эхэлнэ гэсэн үг—чи тийм сургалтыг хүлээн авахад бэлэн байна уу?

Яарсан мэдрэмжтэй байхад бэлэн үү? Бурханы сахилгажуулалт дор амьдрахад бэлэн үү? Бурханы гэсгээлт дор амьдрахад бэлэн үү? Бурханы үг чам дээр ирж, чамайг турших үед чи хэрхэн үйлдэх вэ? Бүх төрлийн баримттай тулгарах үедээ чи юу хийх вэ? Урьд нь чи амь дээр анхаарлаа төвлөрүүлээгүй; өнөөдөр чи амьбодит байдалд орж, амь зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх ёстой. Энэ нь хаанчлалын ардуудын биелүүлэх ёстой зүйл юм. Бурханы ард болох бүх хүн амийг эзэмших ёстой бөгөөд хаанчлалын сургалтыг хүлээн авч, амь зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх ёстой. Хаанчлалын ардуудаас Бурханы шаарддаг зүйл энэ юм.

Хаанчлалын ардуудад Бурхан дараах шаардлагыг тавьдаг:

1. Тэд Бурханы даалгаврыг хүлээн авах ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы эцсийн өдрүүдийн ажилд хэлэгдсэн бүх үгийг хүлээн авах ёстой.
2. Тэд хаанчлалын сургалтад орох ёстой.
3. Тэд зүрх сэтгэлээ Бурханаар хөдөлгүүлэхээр эрэлхийлэх ёстой. Зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрмөсөн эргэж, хэвийн сүнслэг амьдралтай болох үедээ чи эрх чөлөөтэй ертөнцөд амьдарна, энэ нь Бурханы хайрын халамж, хамгаалалт дор амьдарна гэсэн үг юм. Бурханы халамж, хамгаалалт дор амьдрах үедээ л чи Бурханд харьяалагдана.
4. Тэд Бурханаар авхуулах ёстой.
5. Тэд газар дээрх Бурханы алдрын илрэл болох ёстой.

Энэ таван зүйл бол та нарт Миний даалгасан даалгавар юм. Би үгээ Бурханы ардуудад хэлдэг бөгөөд хэрвээ чи эдгээр даалгаврыг хүлээн авах дургүй байгаа бол Би хүчлэхгүй—гэхдээ тэдгээрийг үнэхээр хүлээн авбал чи Бурханы хүслийг биелүүлж чадна. Өнөөдөр та нар Бурханы даалгаврыг хүлээн авч эхэлдэг ба хаанчлалын ардууд болж, хаанчлалын ардуудаас шаарддаг стандартад хүрэхээр эрэлхийлдэг. Энэ нь оролтын эхний алхам юм. Хэрвээ чи Бурханы хүслийг бүрэн биелүүлэхийг хүсвэл энэ таван даалгаврыг хүлээн авах ёстой ба тэдгээрийг биелүүлж чадвал Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж, Бурханд асар их ашиглагдах нь гарцаагүй. Өнөөдрийн хамгийн чухал зүйл бол хаанчлалын сургалтад орох явдал юм. Хаанчлалын сургалтад орох нь сүнслэг амьдралтай хамаатай. Урьд нь сүнслэг амьдралын талаар огт яриагүй, харин өнөөдөр хаанчлалын сургалтад орж эхлэхдээ чи албан ёсоор сүнслэг амьдралд ордог.

Сүнслэг амьдрал гэж ямархуу амьдрал вэ? Сүнслэг амьдрал гэдэг нь, зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрмөсөн эргэсэн, Бурханы хайрыг анхаарч чаддаг амьдрал юм. Энэ нь Бурханы үгэн дотор амьдардаг, зүрх сэтгэлийг чинь өөр юу ч эзэмддэггүй, Бурханы өнөөгийн хүслийг ухаарч чаддаг, мөн үүргээ биелүүлэхийн тулд Ариун Сүнсний өнөөгийн гэрлээр замчлуулдаг амьдрал юм. Хүн, Бурхан хоёрын хоорондох ийм амьдрал нь сүнслэг амьдрал мөн. Хэрвээ чи өнөөдрийн гэрлийг дагаж чаддаггүй бол Бурхантай харилцах харилцаанд чинь зай гарч, тэр ч байтугай таслагдсан байж болох бөгөөд чамд хэвийн сүнслэг амьдрал байдаггүй.

Бурхантай харилцах хэвийн харилцаа нь Бурханы өнөөгийн үгийг хүлээн авсан суурин дээр бий болдог. Чи хэвийн сүнслэг амьдралтай юу? Бурхантай хэвийн харилцаатай юу? Чи Ариун Сүнсний ажлыг дагадаг нэгэн мөн үү? Хэрвээ чи Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг дагаж чаддаг бөгөөд Бурханы үгэн дотроос хүслийг нь ухаарч, эдгээр үгэнд орж чаддаг бол Ариун Сүнсний урсгалыг дагадаг нэгэн мөн. Хэрвээ Ариун Сүнсний урсгалыг дагаж чадахгүй бол үнэнийг эрж хайдаггүй хүн гэдэг чинь эргэлзээгүй. Өөрсдийгөө сайжруулах хүсэлгүй хүмүүсийн дотор Ариун Сүнс ажиллах ямар ч боломжгүй бөгөөд үүний үрээр тийм хүмүүс хүч чадлаа дайчилж хэзээ ч чаддаггүй, үргэлж идэвхгүй байдаг. Өнөөдөр чи Ариун Сүнсний урсгалыг дагадаг уу? Ариун Сүнсний урсгалд байдаг уу? Чи идэвхгүй байдлаас гарсан уу? Бурханы үгэнд итгэдэг, Бурханы ажлыг сууриа болгож, Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг дагадаг бүх хүн Ариун Сүнсний урсгалд байгаа. Хэрвээ чи, Бурханы үг маргаангүй үнэн, зөв гэж итгэдэг бол; Бурхан юу ч хэлсэн бай, үгэнд нь итгэдэг бол Бурханы ажилд орохоор эрэлхийлдэг хүн бөгөөд ийм маягаар чи Бурханы хүслийг биелүүлдэг.

Ариун Сүнсний урсгалд орохын тулд чи Бурхантай хэвийн харилцаатай байх ёстой бөгөөд эхлээд идэвхгүй байдлаасаа ангижрах ёстой. Зарим хүн үргэлж олонхыг дагадаг ба зүрх сэтгэл нь Бурханаас хэтэрхий хол хадуурсан байдаг; тийм хүмүүст өөрсдийгөө сайжруулах ямар ч хүсэл байдаггүй бөгөөд эрэлхийлдэг стандарт нь дэндүү доогуур байдаг. Бурханыг хайрлах, Бурханаар авхуулах эрэл хайгуул л Бурханы хүсэл юм. Бурханы хайрыг хариулахын тулд мөс чанараа л ашигладаг хүмүүс байдаг боловч энэ нь Бурханы хүсэлд нийцэж чадахгүй; чи өндөр стандартыг эрэлхийлэх тусам, энэ нь Бурханы хүсэлтэй төдий чинээ зохицолтой байх болно. Хэвийн хүн болохын хувьд, мөн Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг хүн болохын хувьд хаанчлалд орж, Бурханы ардуудын нэг болох нь та нарын жинхэнэ ирээдүй бөгөөд дээд зэргийн үнэ цэн, ач холбогдолтой амьдрал юм; та нараас илүү ерөөгдсөн хэн ч байхгүй. Би яагаад ингэж хэлдэг вэ? Учир нь Бурханд итгэдэггүй хүмүүс махан биеийн төлөө, Сатаны төлөө амьдардаг, гэхдээ өнөөдөр та нар Бурханы төлөө амьдарч, Бурханы хүслийг биелүүлэхээр амьдардаг. Тийм учраас, та нарын амьдрал дээд зэргийн ач холбогдолтой гэж Би хэлдэг. Бурханы сонгосон энэ бүлэг хүмүүс л дээд зэргийн ач холбогдолтой амьдралыг амьдран харуулж чаддаг: Газар дэлхий дээр өөр хэн ч тийм үнэ цэн, утга учиртай амьдралыг амьдран харуулж чадахгүй. Та нарыг Бурхан сонгож, Бурхан өргөсөн учраас, түүнчлэн та нарыг гэх Бурханы хайраас болж та нар жинхэнэ амьдралд хүрч, дээд зэргийн үнэ цэнэтэй амьдралаар хэрхэн амьдрах тухай мэдсэн. Энэ нь та нарын эрэл хайгуул сайнаас болоогүй, харин Бурханы нигүүлслээс болсон юм; та нарын сүнслэг нүдийг Бурхан нээж, зүрх сэтгэлийг чинь Бурханы Сүнс хөдөлгөж, Түүний өмнө очих сайн зол завшаан өгсөн билээ. Хэрвээ Бурханы Сүнс та нарыг гэгээрүүлээгүй бол та нар Бурханы хайр татам байдлыг харах чадваргүй байх байсан, мөн Бурханыг хайрлах ч боломжгүй байх байсан. Үндсэндээ Бурханы Сүнс хүмүүсийн зүрх сэтгэлийг

хөдөлгөсөн учраас л тэдний зүрх сэтгэл Бурхан руу эргэсэн. Заримдаа Бурханы үгийг таашааж байх үед сүнс чинь хөдөлж, чи өөрийн эрхгүй Бурханыг хайрлаж, дотор чинь асар их хүч чадал байгааг, чиний хувьд хойш тавьж чадахгүй юу ч байхгүй гэдгийг мэдэрдэг. Хэрвээ чамд ингэж санагддаг бол Бурханы Сүнс чамайг хөдөлгөж, зүрх сэтгэл чинь Бурхан руу бүрэн эргэсэн бөгөөд чи Бурханд залбирч, “Өө Бурхан минь! Биднийг үнэхээр Та урьдчилан тогтоож, сонгосон. Таны алдар надад бахархал хайрлаж, Таны ардуудын нэг байх нь миний хувьд алдар цуутай санагддаг. Таны хүслийг биелүүлэхийн тулд би юуг ч зарлагадаж, юуг ч өгнө, өөрийн бүх амьдрал, насан туршийн бүхий л эрч хүчийг Танд зориулна” гэж хэлнэ. Ингэж залбирах үед зүрх сэтгэлд чинь Бурханыг гэх эцэс төгсгөлгүй хайр болон жинхэнэ дуулгавартай байдал байх болно. Чамд ер нь иймэрхүү туршлага байсан уу? Хэрвээ хүмүүсийн сэтгэлийг Бурханы Сүнс үргэлж хөдөлгөдөг бол тэд ялангуяа залбиралдаа өөрсдийгөө Бурханд зориулахад бэлэн байдаг: “Өө Бурхан минь! Би Таны алдрын өдрийг харахыг хүсэж байна, би Таны төлөө амьдрахыг хүсэж байна—Таны төлөө амьдрахаас илүү үнэ цэнтэй, утга учиртай юу ч үгүй бөгөөд надад Сатан болон махан биеийн төлөө амьдрах өчүүхэн төдий ч хүсэл алга. Өнөөдөр Таны төлөө амьдрах боломж олгосноороо Та намайг өргөсөн.” Ийм маягаар залбирах үедээ чи, зүрх сэтгэлээ Бурханд өгөхгүй байж чадахгүй гэдгээ, Бурханыг олж авах ёстойгоо, амьд ахуйдаа Бурханыг олж авалгүйгээр үхэж тэвчихгүй гэдгээ мэдэрнэ. Ийм залбирал хэлсний дараа чиний дотор барагдашгүй их хүч байх ба энэ нь хаанаас ирдгийг чи мэдэхгүй; зүрх сэтгэл чинь хязгааргүй их хүч чадалтай байж, Бурхан бол маш хайр татам, Түүнийг хайрлууштай гэдгийг чи мэдэрнэ. Энэ үед Бурхан сэтгэлийг чинь хөдөлгөсөн байх болно. Ийм туршлагатай бүх хүний сэтгэлийг Бурхан хөдөлгөсөн байдаг. Бурхан үргэлж сэтгэлийг нь хөдөлгөдөг хүмүүсийн амь нь өөрчлөгддөг, тэд шийдвэрээ гаргаж чаддаг, Бурханыг бүрэн олж авахад бэлэн байдаг, зүрх сэтгэл дэх Бурханыг гэх хайр нь илүү хүчтэй байж, зүрх сэтгэл нь Бурхан руу бүрмөсөн эргэсэн байдаг, тэд гэр бүл, дэлхий ертөнц, ээдрээтэй асуудлууд, эсвэл өөрсдийн ирээдүйг тоодоггүй, мөн насан туршийн эрч хүчээ Бурханд зориулахад бэлэн байдаг. Бурханы Сүнсээр хөдөлгөгдсөн бүх хүн бол үнэнийг эрэлхийлдэг, Бурханаар төгс болгуулах итгэл найдвартай хүмүүс юм.

Чи зүрх сэтгэлээ Бурхан руу хандуулсан уу? Чиний зүрх сэтгэлийг Бурханы Сүнс хөдөлгөсөн үү? Хэрвээ чамд тийм туршлага огт байгаагүй бол, хэрвээ чи хэзээ ч ийм маягаар залбирч байгаагүй бол зүрх сэтгэлд чинь Бурхан ямар ч зай эзэлдэггүй гэдгийг энэ нь харуулдаг. Бурханы Сүнсээр замчлуулдаг, Бурханы Сүнсээр хөдөлгөгдсөн бүх хүн Бурханы ажлыг эзэмшдэг нь Бурханы үг болон хайр тэдний дотор үндэслэсэн гэдгийг харуулдаг. Зарим хүн ингэж хэлдэг: “Би залбиралдаа чам шиг чин үнэнч байдаггүй, бас Бурхан миний сэтгэлийг тийм ч их хөдөлгөдөггүй; заримдаа бясалгаж, залбирах үедээ би Бурхан хайр татам гэдгийг мэдэрч, миний зүрх сэтгэлийг Бурхан хөдөлгөдөг.” Хүний зүрх сэтгэлээс илүү чухал юу ч үгүй. Зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэх үед бүхий л оршихуй чинь Бурхан руу

эргэсэн байх ба тэр үед зүрх сэтгэлийг чинь Бурханы Сүнс хөдөлгөсөн байх болно. Та нарын дундаас ихэнхэд нь ийм туршлага байгаа—зүгээр л туршлагын чинь гүн гүнзгий байдал нь адилхан биш. Зарим хүн: “Би залбирлын олон үг хэлдэггүй, зүгээр л бусдын яриаг сонсоод миний доторх хүч чадал нэмэгддэг” гэж хэлдэг. Энэ нь сэтгэлийг чинь Бурхан хөдөлгөсөн гэдгийг харуулдаг. Зүрх сэтгэлийг нь Бурхан хөдөлгөсөн хүмүүс бусдын яриаг сонсох үедээ зоригждог; зоригжуулж урамшуулсан үгийг сонсох үедээ хүний зүрх сэтгэл огт хөдлөхгүй хэвээр байвал Ариун Сүнсний ажил түүний дотор байхгүй гэдгийг энэ нь баталдаг. Тэдний дотор хүсэл эрмэлзэл байдаггүй нь тэдэнд ямар ч шийдвэр байхгүй гэдгийг баталдаг, тиймээс тэдэнд Ариун Сүнсний ажил байдаггүй. Хэрвээ хүний сэтгэлийг Бурхан хөдөлгөсөн бол Бурханы үгийг сонсох үедээ тэрээр хариу үйлдэл үзүүлнэ; харин Бурхан сэтгэлийг нь хөдөлгөөгүй бол тэрээр Бурханы үгтэй холбогдоогүй, тэдгээртэй ямар ч хамаагүй байдаг бөгөөд гэгээрүүлэгдэж чадахгүй. Бурханы үгийг сонссон агаад ямар ч хариу үйлдэлгүй байсан хүмүүс нь Бурханаар хөдөлгөгдөөгүй хүмүүс юм—тэд бол Ариун Сүнсний ажилгүй хүмүүс билээ. Шинэ гэрлийг хүлээн авч чаддаг бүх хүний сэтгэл хөдөлсөн байдаг бөгөөд Ариун Сүнсний ажилтай байдаг.

Өөрийгөө үнэлээрэй:

1. Чи Ариун Сүнсний өнөөгийн ажлын дунд байгаа юу?
2. Зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэсэн үү? Чиний сэтгэлийг Бурхан хөдөлгөсөн үү?
3. Бурханы үг чиний дотор үндэслэсэн үү?
4. Чиний хэрэгжүүлэлт Бурханы шаардлагад суурилсан уу?
5. Чи Ариун Сүнсний өнөөгийн гэрлийн удирдамж дор амьдардаг уу?
6. Чиний зүрх сэтгэлийг хуучин үзэл захирдаг уу, эсвэл Бурханы өнөөгийн үг захирдаг уу?

Эдгээр үгийг сонсоод та нарын доторх хариу үйлдэл юу вэ? Ийм олон жил итгэчхээд чи Бурханы үгийг өөрийн амь болгосон уу? Урьдын завхарсан зан чанарт чинь өөрчлөлт гарсан уу? Бурханы өнөөгийн үгийн дагуу бол, амьтай байх болон амьгүй байх гэж юу гэсэн үг болохыг чи мэдэх үү? Энэ нь та нарт тодорхой байна уу? Бурханыг дагахад хамгийн чухал нь бүх зүйл Бурханы өнөөгийн үгийн дагуу байх ёстой: Чи амийн оролтыг эрэлхийлж байна уу, эсвэл Бурханы хүслийг хангалуун байлгахаар эрэлхийлж байна уу хамаагүй, бүх зүйл Бурханы өнөөгийн үгэнд төвлөрөх ёстой. Хэрвээ чиний ярилцаж, эрэлхийлдэг зүйл Бурханы өнөөгийн үгэнд төвлөрдөггүй бол чи Бурханы үгийн гадна байгаа хүн бөгөөд Ариун Сүнсний ажил огт байхгүй. Өөрийнх нь мөрийг дагадаг хүмүүсийг Бурхан хүсдэг. Урьд нь ойлгосон зүйл чинь хэчнээн гайхалтай, хольцгүй байх нь хамаагүй Бурхан үүнийг хүсдэггүй бөгөөд хэрвээ чи тийм зүйлсийг хойш тавьж чадахгүй бол тэдгээр нь ирээдүйн оролтод чинь асар их саад бартаа болно. Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг дагаж чаддаг бүх хүн ерөөгддөг. Өнгөрсөн эрин үеүдийн хүмүүс ч бас Бурханы мөрийг дагасан, гэхдээ тэд өнөөдрийг хүртэл дагаж чадаагүй; энэ бол

эцсийн өдрүүдийн хүмүүсийн ерөөл юм. Ариун Сүнсний өнөөгийн ажлыг дагаж чаддаг, мөн Бурханы мөрийг дагаж чаддаг, улмаар Бурхан өөрсдийг нь хаашаа ч хөтөлсөн дагадаг хүмүүс бол Бурханаар ерөөгддөг хүмүүс билээ. Ариун Сүнсний өнөөгийн ажлыг дагадаггүй хүмүүс Бурханы үгийн ажилд ороогүй бөгөөд хэчнээн их ажиллаж, хэдий их зовж, хэчнээн ийш тийш гүйлээ ч гэсэн Бурханы хувьд энэ нь ямар ч утгагүй бөгөөд Бурхан тэднийг сайшаахгүй. Өнөөдөр, Бурханы өнөөгийн үгийг дагадаг бүх хүн Ариун Сүнсний урсгалд байдаг; Бурханы өнөөгийн үгээс ангид хүмүүс Ариун Сүнсний урсгалын гадна байдаг бөгөөд тийм хүмүүсийг Бурхан сайшаадаггүй. Ариун Сүнсний өнөөгийн айлдвараас салсан үйлчлэл бол махан биеийн үйлчлэл, үзлийн үйлчлэл бөгөөд Бурханы хүсэлтэй нийцэлтэй байх боломжгүй. Хэрвээ хүмүүс шашны үзэл дунд амьдардаг бол Бурханы хүсэлд нийцэх юу ч хийж чадахгүй бөгөөд Бурханд үйлчиллээ ч гэсэн үзэл, төсөөллийнхөө дунд үйлчлэн, Бурханы хүслийн дагуу үйлчлэх ямар ч чадваргүй байдаг. Ариун Сүнсний ажлыг дагаж чаддаггүй хүмүүс Бурханы хүслийг ойлгодоггүй ба Бурханы хүслийг ойлгодоггүй хүмүүс Бурханд үйлчилж чадахгүй. Бурхан Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух үйлчлэлийг хүсдэг; харин үзлийн болон махан биеийн үйлчлэлийг хүсдэггүй. Хүмүүс Ариун Сүнсний ажлын алхмуудыг дагах чадваргүй бол үзэл дунд амьдардаг. Ийм хүмүүсийн үйлчлэл саад болж, төвөг уддаг бөгөөд ийм үйлчлэл Бурханы эсрэг байдаг. Тиймээс Бурханы мөрийг дагаж чаддаггүй хүмүүс Бурханд үйлчилж чаддаггүй; Бурханы мөрийг дагаж чаддаггүй хүмүүс Бурханыг гарцаагүй эсэргүүцдэг ба Бурхантай нийцэлтэй байж чаддаггүй. “Ариун Сүнсний ажлыг дагах” гэдэг нь Бурханы өнөөгийн хүслийг ойлгож, Бурханы өнөөгийн шаардлагын дагуу үйлдэж чаддаг байж, өнөөдрийн Бурханд захирагдаж, Түүнийг дагаж, Бурханы хамгийн шинэ айлдваруудын дагуу орж чаддаг байна гэсэн үг юм. Зөвхөн энэ л Ариун Сүнсний ажлыг дагадаг, Ариун Сүнсний урсгалд байдаг хүн юм. Тийм хүмүүс Бурханы сайшаалыг хүртэж, Бурханыг харж чаддаг төдийгүй хамгийн сүүлийн үеийн ажлаас нь Бурханы зан чанарыг мэдэж, хүний үзэл, дуулгаваргүй байдал, уг чанар болон мөн чанарыг мэдэж чаддаг; түүнчлэн тэд үйлчлэлийнхээ үеэр өөрсдийн зан чанарыг аажмаар өөрчилж чаддаг. Ийм хүмүүс л Бурханыг олж авах чадвартай, үнэн замыг үнэхээр олсон хүмүүс юм. Ариун Сүнсний ажлаар таягдан хаягддаг хүмүүс бүгдээрээ Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлыг дагаж чаддаггүй, харин Бурханы хамгийн сүүлийн үеийн ажилд тэрсэлдэг хүмүүс юм. Тийм хүмүүс Бурханыг илт эсэргүүцдэг нь Бурхан шинэ ажил хийснээс болдог, мөн Бурханы дүр, өөрсдийнх нь үзэлд байдаг дүрээс өөр байгаагаас болдог—иймээс тэд Бурханыг илт эсэргүүцэж, шүүж, улмаар Бурхан тэднийг жигшин голоход хүрдэг. Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлын талаар мэдэх нь амархан хэрэг биш боловч хэрвээ хүмүүс Бурханы ажлыг дуулгавартай дагаж, Бурханы ажлыг эрж хайх санаатай байвал Бурханыг харж, Ариун Сүнсний шинэхэн удирдамжийг олж авах боломжтой байх болно. Бурханы ажлыг зориуд эсэргүүцдэг хүмүүс Ариун Сүнсний гэгээрэл юм уу Бурханы удирдамжийг хүлээн авч чадахгүй. Тиймээс хүмүүс Бурханы хамгийн

сүүлийн үеийн ажлыг хүлээн авч чадах уу, үгүй юу гэдэг нь Бурханы нигүүлслээс хамаардаг, мөн тэдний эрэл хайгуул болон санаа зорилгоос хамаардаг.

Ариун Сүнсний өнөөгийн айлдваруудыг дуулгавартай дагаж чаддаг бүх хүн ерөөгддөг. Тэд өмнө нь ямар байсан, эсвэл Ариун Сүнс тэдэн дотор хэрхэн ажилладаг байсан нь хамаагүй—Бурханы хамгийн сүүлийн үеийн ажлыг олж авсан хүмүүс хамгийн их ерөөгддөг бөгөөд өнөөдөр хамгийн сүүлийн үеийн ажлыг дагаж чаддаггүй хүмүүс таягдан хаягддаг. Бурхан шинэ гэрлийг хүлээн авч чаддаг хүмүүсийг хүсдэг бөгөөд Өөрийнх нь хамгийн сүүлийн үеийн ажлыг хүлээн авдаг, мэддэг хүмүүсийг хүсдэг. Та нарыг ухаалаг охид байх ёстой гэж яагаад хэлдэг вэ? Ухаалаг охид Ариун Сүнсний ажлыг эрж хайж, шинэ зүйлсийг ойлгож, цаашлаад хуучин үзлээ хойш тавьж, Бурханы өнөөдрийн ажлыг дуулгавартай дагаж чаддаг. Өнөөдрийн шинэ ажлыг хүлээн авдаг энэ бүлэг хүмүүсийг Бурхан аль эрт урьдчилан тогтоосон бөгөөд хамгийн их ерөөгдсөн хүмүүс билээ. Та нар Бурханы дуу хоолойг шууд сонсож, Бурханы илрэлтийг хардаг, иймээс тэнгэр газар даяар, эрин үеүдийн туршид хэн ч энэ бүлэг хүмүүс та нараас илүү ерөөгдөөгүй. Энэ бүхэн нь Бурханы ажлаас, Бурханы урьдчилан тогтоолт, сонголтоос, мөн Бурханы нигүүлслээс болж байгаа; хэрвээ Бурхан үг хэлж, Өөрийн үгийг айлдаагүй бол та нарын нөхцөл байдал өнөөдрийнх шиг байж чадах уу? Тиймээс Бурханд бүх алдар, магтаал нь байх болтугай, учир нь энэ бүхэн Бурхан та нарыг өргөснөөс болж байгаа юм. Чи эдгээр зүйлийг бодох үедээ идэвхгүй хэвээр байж чадах уу? Хүч чадлаа нэмэгдүүлж чадахгүй хэвээр байх уу?

Өнөөдөр Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, цохилт, цэвэршүүлэлтийг хүлээн авч, түүнчлэн Бурханы даалгаврыг хүлээн авч чадаж байгаа чинь эрин үеүдээс өмнө Бурханаар урьдчилан тогтоогдсон, тиймээс чи гэсгээгдэх үедээ хэтэрхий их гутрах ёсгүй. Та нарт хийгдсэн ажлыг болон та нарт хайрласан ерөөлийг хэн ч булаан авч чадахгүй, мөн та нарт өгсөн бүхнийг хэн ч булаан авч чадахгүй. Шашны хүмүүсийг та нартай харьцуулах аргагүй. Та нар Библийг тийм ч сайн мэддэггүй, шашны онолоор зэвсэглээгүй боловч Бурхан та нарын дотор ажилласан учраас та нар эрин үеүдийн туршид байсан хэнээс ч илүү ихийг олж авсан—иймээс энэ нь та нарын хамгийн агуу ерөөл билээ. Үүнээс үүдэн та нар Бурханд өөрсдийгөө бүр ч их зориулж, бүр ч их үнэнч байх ёстой. Бурхан чамайг өргөсөн учраас чи хичээл чармайлтаа нэмэгдүүлэх ёстой бөгөөд Бурханы даалгаврыг хүлээн авахад биеийн хэмжээгээ бэлдэх ёстой. Чи Бурханы өгсөн байр сууринд бат зогсож, Бурханы ардуудын нэг болохоор зорьж, хаанчлалын сургалтыг хүлээн авч, Бурханаар авхуулж, эцэст нь Бурханы алдар суут гэрчлэл болох ёстой. Ийм шийдвэр чамд байгаа юу? Хэрвээ чамд тийм шийдвэр байгаа бол эцэстээ чи Бурханаар авхуулж, Бурханы алдар суут гэрчлэл болох нь гарцаагүй. Гол чухал даалгавар бол Бурханаар авхуулж, Бурханы алдар суут гэрчлэл болох явдал гэдгийг чи ойлгох ёстой. Энэ нь Бурханы хүсэл билээ.

Ариун Сүнсний өнөөгийн үг бол Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн бөгөөд энэ хугацаанд Ариун Сүнс хүнийг байнга гэгээрүүлдэг нь Ариун Сүнсний ажлын чиг

хандлага юм. Тэгвэл Ариун Сүнсний өнөөгийн ажлын чиг хандлага юу вэ? Энэ нь, хүмүүсийг Бурханы өнөөгийн ажил руу, хэвийн сүнслэг амьдрал руу удирдах явдал юм. Хэвийн сүнслэг амьдралд орох оролтод хэд хэдэн алхам бий:

1. Эхлээд чи зүрх сэтгэлээ Бурханы үгэнд зориулах ёстой. Чи Бурханы урьдын үгийг эрэлхийлэх ёсгүй бөгөөд тэдгээрийг судалж, эсвэл өнөөдрийн үгтэй харьцуулах ёсгүй. Харин ч чи өөрийнхөө зүрх сэтгэлийг Бурханы өнөөгийн үгэнд бүрмөсөн зориулах ёстой. Өнгөрсөн үеийн Бурханы үг, сүнслэг номууд, эсвэл бусад номлолын тэмдэглэлүүдийг уншихыг хүсдэг бөгөөд Ариун Сүнсний өнөөгийн үгийг дагадаггүй хүмүүс байвал тэд хамгийн тэнэг хүмүүс юм; Бурхан тийм хүмүүсийг жигшдэг. Хэрвээ чи Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг хүлээн авахад бэлэн байгаа бол зүрх сэтгэлээ Бурханы өнөөгийн айлдваруудад бүрмөсөн зориул. Энэ бол чиний биелүүлэх ёстой эхний зүйл юм.
2. Чи Бурханы өнөөдөр хэлсэн үгийн суурин дээр залбирч, Бурханы үгэнд орж, Бурхантай ярилцаж, Бурханы өмнө шийдвэр гаргаж, ямар стандартыг биелүүлэхээр зорих гэж байгаагаа тодорхойлох ёстой.
3. Чи Ариун Сүнсний өнөөгийн ажлын суурин дээр үнэнд гүн гүнзгий орохоор эрэлхийлэх ёстой. Урьдын хуучирсан айлдвар болон онолуудтай бүү зууралд.
4. Чи Ариун Сүнсээр хөдөлгөгдөхөөр эрж хайж, Бурханы үгэнд орох ёстой.
5. Өнөөдөр Ариун Сүнсний явж буй замд орохоор эрэлхийлэх ёстой.

Чи яаж Ариун Сүнсээр хөдөлгүүлэхээр эрж хайдаг вэ? Гол чухал зүйл бол Бурханы өнөөгийн үгэн дотор амьдарч, Бурханы шаардлагад суурилан залбирах явдал юм. Ийм маягаар залбирахад Ариун Сүнс гарцаагүй чиний сэтгэлийг хөдөлгөнө. Хэрвээ чи Бурханы өнөөдөр хэлсэн үгэнд үндэслэн эрж хайдаггүй бол энэ нь үр дүнгүй. Чи залбирч, ингэж хэлэх ёстой: “Өө Бурхан минь! Би Таныг эсэргүүцдэг, бас Танд маш их өртэй; би маш дуулгаваргүй агаад Таныг хангалуун байлгаж хэзээ ч чаддаггүй. Өө Бурхан минь, Та намайг авраасай гэж би хүсэж байна, эцсээ хүртэл Танд үйлчлэл үзүүлэхийг хүсэж байна, Таны төлөө үхэхийг хүсэж байна. Та намайг шүүж, гэсгээдэг, гэхдээ надад ямар ч гомдол байхгүй; би Таныг эсэргүүцдэг ба үхвэл таарна, ингэснээр бүх хүн миний үхлээс Таны зөвт зан чанарыг харж болох юм.” Ийм маягаар зүрх сэтгэлийнхээ гүнээс залбирах үед чинь Бурхан чамайг сонсож, чамайг залж чиглүүлнэ; хэрвээ чи Ариун Сүнсний өнөөгийн үгийн суурин дээр залбирдаггүй бол Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөх боломжгүй. Хэрвээ чи Бурханы хүслийн дагуу, Бурханы өнөөдөр хийхийг хүсэж байгаа зүйлийн дагуу залбирдаг бол ингэж хэлнэ: “Өө Бурхан минь! Би Таны даалгаврыг хүлээн авч, Таны даалгаварт үнэнч байхыг хүсэж байна, хийж байгаа бүхнээ Бурханы ардуудын стандартад хүргэхийн тулд бүхий л амьдралаа Таны алдрын төлөө зориулахыг хүсэж байна. Та миний сэтгэлийг хөдөлгөх болтугай. Таны Сүнс намайг үргэлж гэгээрүүлж, миний хийдэг бүхнээр Сатаныг шившиглэж, эцэст нь Та намайг олж аваасай гэж хүсэж байна.” Хэрвээ чи Бурханы хүсэл дээр төвлөрөн ийм маягаар залбирвал Ариун Сүнс гарцаагүй чиний дотор ажиллана.

Залбирлын чинь үг хэчнээн олон байх нь хамаагүй—Бурханы хүслийг ухаарсан уу, үгүй юу гэдэг чинь гол нь юм. Та нарт бүгдэд нь дараах туршлага байгаа байх: Заримдаа цуглаан дээр залбирч байхад Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн оргилдоо хүрч, хүн бүрийн хүч чадлыг нэмэгдүүлдэг. Зарим хүн залбирах зуураа гашуунаар уйлан, нулимс асгаруулж, Бурханы өмнө харуусалд автдаг ба зарим хүн шийдвэрээ харуулж, тангараг өргөдөг. Тэр нь Ариун Сүнсний ажлаар хүрдэг үр дүн юм. Өнөөдөр бүх хүн Бурханы үгэнд зүрх сэтгэлээ зориулах нь хамгийн чухал. Урьд нь хэлэгдсэн үгэнд бүү төвлөр; хэрвээ чи өмнө нь болж өнгөрсөн зүйлтэй зууралдсаар байвал Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй. Энэ нь хэчнээн чухал болохыг чи харав уу?

Та нар Ариун Сүнсний өнөөгийн алхаж байгаа замыг мэдэх үү? Дээр дурдсан хэдэн зүйл бол өнөөдөр, бас ирээдүйд Ариун Сүнсний гүйцэлдүүлэх зүйл юм; тэдгээр нь Ариун Сүнсний явдаг зам бөгөөд хүний эрэлхийлэх учиртай оролт билээ. Амийн оролтдоо чи ядаж л зүрх сэтгэлээ Бурханы үгэнд зориулж, Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн авч чаддаг байх ёстой; чиний зүрх сэтгэл Бурханыг хүсэн эрмэлзэх ёстой ба чи үнэний гүн гүнзгий оролтыг болон Бурханы шаардсан зорилгыг эрэлхийлэх ёстой. Чамд ийм хүч чадал байгаа бол сэтгэлийг чинь Бурхан хөдөлгөж, зүрх сэтгэл чинь Бурхан руу хандаж эхэлснийг энэ нь харуулдаг.

Амийн оролтын эхний алхам нь зүрх сэтгэлээ Бурханы үгэнд бүрэн зориулах явдал бөгөөд хоёр дахь алхам нь Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөхийг хүлээн авах явдал юм. Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөхийг хүлээн авснаар хүрэх үр дүн юу вэ? Энэ нь, илүү гүн гүнзгий үнэнийг хүсэн эрмэлзэж, эрж хайж, судалж шинжлэх чадвартай байх болон эерэг байдлаар Бурхантай хамтран ажиллах чадвартай байх явдал юм. Өнөөдөр чи Бурхантай хамтран ажилладаг, өөрөөр хэлбэл, эрж хайж, залбирч, Бурханы үгийг ярилцахдаа зорилготой байдаг ба Бурханы шаардлагад нийцүүлэн үүргээ биелүүлдэг—зөвхөн энэ л Бурхантай хамтран ажиллах явдал юм. Хэрвээ чи Бурханаар хийлгэх тухай л ярьдаг боловч өөрөө ямар ч үйлдэл хийдэггүй, залбирдаггүй, бас эрж хайдаггүй бол үүнийг яаж хамтын ажиллагаа гэж нэрлэж болох юм бэ? Хэрвээ чамд хүний хамтын ажиллагааны ямар ч ул мөр байхгүй, зорилго бүхий оролтын сургалт байхгүй бол үүнийг хамтран ажиллаж байна гэж хэлэхгүй. Зарим хүн: “Бүх зүйл Бурханы урьдчилан тогтоолтоос хамаардаг, энэ бүгдийг Бурхан Өөрөө хийдэг; хэрвээ Бурхан үүнийг хийгээгүй бол хүн яаж чадах юм бэ?” гэдэг. Бурханы ажил хэвийн, өчүүхэн төдий ч ер бусын зүйлгүй бөгөөд идэвхтэй эрж хайснаар чинь л дамжуулан Ариун Сүнс ажилладаг, учир нь Бурхан хүнийг хүчилдэггүй—чи Бурханд ажиллах боломж олгох ёстой ба эрж хайдаггүй, эсвэл ордоггүй, өчүүхэн төдий ч хүсэн тэмүүлэх зүрх сэтгэлгүй бол Бурхан огт ажиллах боломжгүй. Бурханаар хөдөлгөгдөхийн тулд чи ямар замаар эрж хайж болох вэ? Залбирлаар, мөн Бурхантай ойр дотно болсноор. Гэхдээ хамгийн чухал нь, энэ нь Бурханы хэлсэн үгэнд үндэслэх ёстойг сана. Бурхан сэтгэлийг чинь байнга хөдөлгөх үед чи махан биед захирагддаггүй: Нөхөр, эхнэр,

хүүхдүүд, мөнгө—тэдгээр нь бүгд чамайг дөнгөлөх чадваргүй бөгөөд чи үнэнийг эрэлхийлж, Бурханы өмнө амьдрахыг л хүснэ. Энэ үед чи эрх чөлөөт ертөнцөд амьдардаг хүн байх болно.

ЗАН ЧАНАР НЬ ӨӨРЧЛӨГДСӨН ХҮМҮҮС БОЛ БУРХАНЫ ҮГИЙН БОДИТ БАЙДАЛД ОРСОН ХҮМҮҮС ЮМ

Хүн доторх Ариун Сүнсний замын эхний алхам нь юун түрүүнд хүний зүрх сэтгэлийг хүмүүс, үйл явдал, юмсаас татаж авч, Бурханы үгэнд оруулж, улмаар Бурханы үг ямар ч эргэлзээгүй, тэр чигтээ үнэн гэдгийг хүний зүрх сэтгэлд итгүүлэх явдал юм. Чи Бурханд итгэдэг бол Түүний үгэнд итгэх ёстой; Бурханд олон жил итгэснийхээ дараа Ариун Сүнсний сонгосон замыг мэдэхгүй хэвээр байдаг бол чи үнэхээр итгэгч мөн үү? Хэвийн хүний амьдрал буюу Бурхантай хэвийн харилцаатай хэвийн хүний амьдралд хүрэхийн тулд чи эхлээд Түүний үгэнд итгэх ёстой. Хэрвээ чи Ариун Сүнсний хүмүүст хийдэг ажлын эхний алхамд хүрээгүй байгаа бол чамд ямар ч суурь алга. Бүр хамгийн наад захын зарчимд ч хүрч чадахгүй бол чи урдах замаараа яаж алхах юм бэ? Бурханы, хүнийг төгс болгодог зөв замд хөл тавих гэдэг нь Ариун Сүнсний одоогийн ажлын зөв замд орно гэсэн үг юм; энэ нь Ариун Сүнсний алхдаг замд хөл тавина гэсэн үг. Яг одоо, Ариун Сүнсний алхдаг зам бол Бурханы одоогийн үг юм. Тиймээс хэрвээ хүмүүс Ариун Сүнсний замд хөл тавья гэвэл дуулгавартай байж, бие махбодтой болсон Бурханы одоогийн үгийг идэж уух ёстой. Түүний хийдэг ажил бол үгийн ажил юм; бүх зүйл Түүний үгээс эхэлж, бүх зүйл Түүний үгэнд, Түүний одоогийн үгэнд суурилдаг. Бие махбодтой болсон Бурханы талаар итгэлтэй байх ч бай, эсвэл бие махбодтой болсон Бурханыг мэдэх ч бай, аль аль нь Түүний үгэнд илүү их хичээл чармайлт гаргахыг шаарддаг. Эс бөгөөс хүмүүс юу ч хийж чадахгүй бөгөөд юу ч үгүй хоцорно. Бурханы үгийг идэж уусны үндсэн дээр Түүнийг мэдэж, Түүнийг сэтгэл хангалуун байлгаж эхэлснээр л хүмүүс аажмаар Бурхантай хэвийн харилцаа тогтоож чадна. Хүний хувьд Бурханы үгийг идэж уун, хэрэгжүүлэхээс илүү дээр хамтын ажиллагаа гэж үгүй. Ийм хэрэгжүүлэлтээр дамжуулан тэд Бурханы ардын гэрчлэлдээ бат зогсож хамгийн сайн чаддаг. Хүмүүс Бурханы одоогийн үгийн мөн чанарыг ойлгож, дуулгавартай дагаж чадах үедээ Ариун Сүнсний залж чиглүүлдэг зам дээр амьдарч, Бурханаар төгс болгуулах зөв замд хөл тавьсан байдаг. Урьд нь хүмүүс зүгээр л Бурханы нигүүлслийг эрж хайж, амар амгалан, баяр хөөрийг эрэлхийлснээр Бурханы ажлыг олж авч чаддаг байсан боловч одоо юмс өөр болсон. Бие махбодтой болсон Бурханы үг байхгүй бол, Түүний үгийн бодит байдал байхгүй бол хүмүүс Бурханы сайшаалыг олж авч чадахгүй бөгөөд бүгд Бурханд таягдуулан хаягдана. Хэвийн сүнслэг амьдралд хүрэхийн тулд хүмүүс эхлээд Бурханы үгийг идэж ууж, хэрэгжүүлээд, дараа нь энэ суурин дээрээ Бурхантай хэвийн харилцаа тогтоох

ёстой. Чи яаж хамтран ажилладаг вэ? Чи Бурханы ардын гэрчлэлд хэрхэн бат зогсдог вэ? Чи яаж Бурхантай хэвийн харилцаа тогтоодог вэ?

Өдөр тутмынхаа амьдралд Бурхантай хэвийн харилцаатай байна уу гэдгээ хэрхэн шалгах вэ:

1. Чи Бурханы Өөрийнх нь гэрчлэлд итгэдэг үү?
2. Чи зүрх сэтгэлдээ Бурханы үг бол үнэн бөгөөд алдаа мадаггүй гэдэгт итгэдэг үү?
3. Чи Түүний үгийг хэрэгжүүлдэг хүн мөн үү?
4. Түүний чамд даалгасан зүйлд чи үнэнч байдаг уу? Түүний даалгаварт үнэнч байхын тулд чи юу хийдэг вэ?
5. Чиний хийдэг бүхэн Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, Бурханд үнэнч байхын төлөө байдаг уу?

Дээр жагсаасан зүйлсийг ашиглаад чи өнөөгийн энэ үе шатанд Бурхантай хэвийн харилцаатай байгаа эсэхээ үнэлж дүгнэж болно.

Хэрэв чи Бурханы даалгаврыг хүлээн авч, Түүний амлалтыг хүлээн авч, Ариун Сүнсний замыг дагаж чаддаг бол Бурханы хүслийг дагаж байна гэсэн үг. Ариун Сүнсний зам дотор чинь тодорхой байдаг уу? Яг одоо чи Ариун Сүнсний замд нийцүүлэн үйлддэг үү? Чиний зүрх сэтгэл Бурханд ойртож байна уу? Чи Ариун Сүнсний хамгийн шинэ гэрэлтэй хөл нийлүүлэхийг хүсэж байна уу? Чи Бурханаар авхуулахыг хүсэж байна уу? Бурханы газар дээрх алдрын илрэл болохыг хүсэж байна уу? Бурханы шаарддаг зүйлд хүрэх шийдвэр чамд байдаг уу? Бурханыг үг хэлэх үед дотор чинь хамтран ажиллах шийдвэр болон Бурханыг хангалуун байлгах шийдвэр байдаг бол—хэрвээ энэ нь чиний сэтгэлгээ бол—Бурханы үг чиний зүрх сэтгэлд үр дүнд хүрчээ гэсэн үг. Хэрэв чамд тийм шийдвэр байхгүй бөгөөд эрэлхийлдэг зорилго байхгүй бол зүрх сэтгэлийг чинь Бурхан хөдөлгөөгүй гэсэн үг юм.

Хүмүүс хаанчлалын сургуулилтад албан ёсоор ормогц тэдэнд тавих Бурханы шаардлага илүү өндөр түвшид очдог. Энэ илүү өндөр шаардлагыг юунаас харж болох вэ? Урьд нь, хүмүүст амь байхгүй гэж хэлдэг байсан. Өнөөдөр тэд амийг эрж хайж, Бурханы ардууд болохыг, Бурханаар авхуулахыг, Бурханаар төгс болгуулахыг зорьдог. Энэ нь илүү өндөр түвшин бус уу? Үнэндээ, хүмүүст тавьдаг Бурханы шаардлага өмнө байснаасаа илүү энгийн болсон. Хүмүүсээс үйлчлэл үзүүлэгч болохыг, эсвэл үхэхийг шаарддаггүй—Бурханы ард болохыг л шаарддаг. Энэ нь илүү энгийн бус уу? Чиний хийх ёстой ганц зүйл гэвэл зүрх сэтгэлээ Бурханд өргөн барьж, Түүний удирдамжид захирагдах ёстой, тэгвээс бүх зүйл биелнэ. Энэ чамд яагаад тийм хэцүү гэж санагддаг юм бэ? Амь руу орох тухай өнөөдөр ярьсан зүйл өмнөхөөсөө илүү тодорхой байдаг. Урьд нь хүмүүс будлиад, үнэн-бодит байдал гэж юу болохыг мэддэггүй байсан. Үнэн хэрэгтээ, Бурханы үгийг сонсох үедээ хариу үйлдэл хийдэг, Ариун Сүнсээр гэгээрүүлэгдэж, гэрэлтүүлэгддэг, Бурханы өмнө төгс болгуулж, зан чанараа өөрчилдөг бүх хүн амьтай байдаг. Бурхан үхмэл зүйлсийг бус, амьд оршихуйг хүсдэг; хэрвээ чи үхмэл бол чамд амь

байхгүй, Бурхан чамтай ярихгүй, тэр ч бүү хэл чамайг Өөрийн ардын нэг болгон өргөхгүй. Нэгэнт та нар Бурханаар өргөгдөж, Түүнээс ийм агуу ерөөл хүлээн авсан тул та нар бүгд амьтай хүмүүс бөгөөд амьтай хүмүүс Бурханаас ирдэг гэдгийг энэ нь харуулдаг.

Хүний амь зан чанарыг өөрчлөх эрэл хайгуулд хэрэгжүүлэлтийн зам энгийн байдаг. Хэрвээ бодит туршлагаараа чи Ариун Сүнсний одоогийн үгийг дагаж, Бурханы ажлыг туулж чаддаг бол зан чанар чинь өөрчлөгдөж чадна. Хэрвээ чи Ариун Сүнсний хэлсэн бүхнийг дагаж, эрж хайдаг бол Түүнд дуулгавартай нэгэн бөгөөд зан чанарт чинь өөрчлөлт гарна. Хүмүүсийн зан чанар Ариун Сүнсний одоогийн үгээр өөрчлөгддөг; хэрвээ чи өнгөрсөн үеийн хуучин туршлага, дүрэм журамтай үргэлж зууралддаг бол зан чанар чинь өөрчлөгдөж чадахгүй. Ариун Сүнсний өнөөдрийн үг бүх хүнээс хэвийн хүн чанарын амьдралд орохыг шаарддаг ч чи гадна талын зүйлд төвлөрсөн хэвээр байж, бодит байдлын талаар төөрөлдөж, нухацтай авч үздэггүй бол Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлж чадаагүй нэгэн, Ариун Сүнсний удирдамжийн замд ороогүй нэгэн юм. Зан чанар чинь өөрчлөгдөж чадах эсэх нь Ариун Сүнсний одоогийн үгтэй хөл нийлүүлдэг эсэхээс чинь, чамд жинхэнэ мэдлэг байгаа эсэхээс хамаардаг. Энэ нь та нарын урьд нь ойлгож байсантай адилгүй. Урьд нь чиний ойлгосон зан чанарын өөрчлөлт бол, түргэн шүүдэг чиний хувьд Бурханы сахилгажуулалтаар дамжуулан бодлогогүй ярихаа болих явдал байсан; гэхдээ энэ бол өөрчлөлтийн ердөө нэг тал. Яг одоо хамгийн чухал нь Ариун Сүнсний удирдамжийг дагах явдал: Бурханы хэлсэн бүхнийг дагаж, хэлсэн бүхэнд нь дуулгавартай бай. Хүмүүс зан чанараа өөрсдөө өөрчилж чаддаггүй; тэд Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, зовлон, цэвэршүүлэлтийг туулж, эсвэл Түүний үгийн харьцалт, сахилгажуулалт, засалтыг туулах ёстой. Тэр үед л тэд Бурханд дуулгавартай, үнэнч болж чадах бөгөөд Түүнд хааш яаш хандахаа болино. Бурханы үгийн цэвэршүүлэлт дор хүмүүсийн зан чанар өөрчлөгддөг. Түүний үгийн илчлэлт, шүүлт, сахилгажуулалт, харьцалтыг туулснаар л хүмүүс болчимгүй авирлаж зүрхлэхээ болиод, харин ч тууштай, тайван болно. Хамгийн чухал нь тэд хүний үзлүүдтэй нийцэхгүй байсан ч гэсэн Бурханы одоогийн үг, ажилд захирагдаж чаддаг бөгөөд тэдгээр үзлийг орхиж, дуртайяа захирагдаж чаддаг. Урьд нь зан чанарын өөрчлөлтийн тухай яриа нь гол төлөв өөрийгөө хаяж, махан биеийг зовоох, өөрийн биеийг сахилгажуулах, махан биеийн дур сонирхлоос ангижрах тухай байсан—энэ нь нэг төрлийн зан чанарын өөрчлөлт юм. Зан чанарын өөрчлөлтийн жинхэнэ илэрхийлэл нь Бурханы одоогийн үгэнд дуулгавартай байж, Түүний шинэ ажлыг үнэхээр мэдэх явдал гэдгийг одоо хүн бүр мэддэг болжээ. Ийм маягаар, хүмүүсийн өөрсдийнх нь үзлээр будагдсан байсан Бурханы талаарх урьдын ойлголтыг арилгаж болох бөгөөд хүмүүс Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй болж, Түүнд дуулгавартай болж чадна—энэ нь л зан чанарын өөрчлөлтийн жинхэнэ илэрхийлэл юм.

Амийн оролтын талаарх хүмүүсийн эрэл хайгуул нь Бурханы үгэнд үндэслэдэг. Урьд нь Түүний үгээс үүдэн бүх зүйл гүйцэлддэг гэж хэлдэг байсан ч хэн ч энэ баримтыг олж хараагүй. Хэрвээ чи одоогийн алхмыг туулбал бүх юм тодорхой болох ба чи ирээдүйн шалгалтуудад зориулан сайн суурь тавих болно. Бурхан юу ч хэллээ гэсэн гагцхүү Түүний үг рүү ороход анхаарлаа төвлөрүүл. Хүмүүсийг гэсгээж эхэлнэ гэж Бурханыг хэлэх үед Түүний гэсгээлтийг хүлээн ав. Бурхан хүмүүсээс үхэхийг шаардах үед тэрхүү шалгалтыг хүлээн ав. Хэрвээ чи үргэлж Түүний хамгийн шинэ айлдварууд дотор амьдарч байгаа бол эцэст нь Бурханы үг чамайг төгс болгоно. Бурханы үг рүү орох тусам чи төдий чинээ хурдан төгс болгуулна. Би яагаад ахин дахин нөхөрлөл хийж, та нараас Бурханы үгийг мэдэж, Бурханы үг рүү орохыг шаарддаг вэ? Бурханы үгийг эрэлхийлж, туулж, Түүний үгийн бодит байдалд орох үед чинь л Ариун Сүнс чиний дотор ажиллах боломжтой болдог. Тиймээс та нар бүгд Бурханы ажилладаг арга барил бүрд оролцогчид бөгөөд зовлон зүдүүр чинь ямар ч хэмжээтэй байсан бай, эцэст нь бүгд “бэлэг дурсгал” хүртэнэ. Эцсийн төгс төгөлдөрт хүрэхийн тулд чи Бурханы бүх үгэнд орох ёстой. Ариун Сүнс хүмүүсийг төгс болгохдоо нэг талыг баримталдаггүй; Тэрээр хүмүүсийн хамтын ажиллагааг шаарддаг ба хүн бүр Түүнтэй ухамсартайгаар хамтран ажиллах хэрэгтэй байдаг. Бурхан юу ч хэлдэг бай, Түүний үгэнд ороход л анхаарлаа төвлөрүүл—энэ нь аминд чинь илүү ашиг тустай байх болно. Бүх зүйл та нарын зан чанарыг өөрчлөхийн төлөө байдаг. Бурханы үгэнд орох үед зүрх сэтгэлийг чинь Тэр хөдөлгөж, ажлынхаа энэ алхамд Бурханы хүрэхийг хүсдэг бүхнийг чи ойлгож чадах бөгөөд үүнд хүрэх шийдвэртэй болно. Гэсгээлтийн цаг үед зарим хүн үүнийг ажлын арга барил гэж үзээд, Бурханы үгэнд итгээгүй. Үр дүнд нь тэд цэвэршүүлэлт туулаагүй бөгөөд ямар нэг зүйлийг олж авч, ойлголгүйгээр гэсгээлтийн цаг үеэс гарч ирсэн юм. Өчүүхэн ч эргэлзэлгүйгээр эдгээр үгэнд үнэхээр орсон, мөн Бурханы үг бол алдаа мадаггүй үнэн бөгөөд хүмүүс гэсгээгдэх ёстой гэж хэлдэг байсан зарим хүн бий. Тэд тэндээ хэсэг хугацаанд тэмцээд, өөрсдийн ирээдүй, хувь заяаг орхисон бөгөөд гарч ирэх үедээ зан чанартаа зарим нэг өөрчлөлт гаргаж, Бурханы талаар илүү гүнзгий ойлголттой болсон байлаа. Гэсгээлтээс гарч ирсэн хүмүүс бүгд Бурханы хайр татам байдлыг мэдэрсэн бөгөөд ажлын энэ алхам бол өөрсдөд нь буун ирж буй Бурханы агуу хайрын биелэл гэдгийг, мөн Бурханы хайрын байлдан дагуулалт, аврал гэдгийг ухаарчээ. Бас тэд Бурханы бодол үргэлж сайн байдаг бөгөөд хүнд Бурханы хийдэг бүхэн үзэн ядалтаас бус, хайраас гардаг гэж хэлсэн юм. Бурханы үгэнд итгээгүй, эсвэл Түүний үгийг анхааралгүй хүмүүс гэсгээлтийн цаг үед цэвэршүүлэлт туулаагүй бөгөөд үүний үр дүнд Ариун Сүнс тэдэнтэй хамт байгаагүй, тэд юу ч олж аваагүй. Гэсгээлтийн цаг үед орсон хүмүүсийн хувьд, хэдий тэд цэвэршүүлэлт туулсан ч Ариун Сүнс тэдний дотор нуугдмал байдлаар ажиллаж байсан ба үр дүнд нь тэдний амь зан чанар өөрчлөгджээ. Зарим хүн гаднаа маш эерэг, бүхэл өдөржингөө хөөр баяслаар дүүрэн байсан ч Бурханы үгийн цэвэршүүлэлтийн байдалд ороогүй

байсан тул огтхон ч өөрчлөгдөөгүй юм, энэ нь Бурханы үгэнд итгээгүйн үр дагавар байв. Хэрвээ чи Бурханы үгэнд итгэдэггүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй. Бурхан Өөрийнх нь үгэнд итгэдэг бүх хүнд харагддаг ба Түүний үгэнд итгэж, Түүний үгийг хүлээн авдаг хүмүүс Түүний хайрыг олж авч чадна!

Бурханы үгийн бодит байдалд орохын тулд хэрэгжүүлэлтийн замыг олж, Бурханы үгийг хэрхэн хэрэгжүүлэхээ мэдэх ёстой. Ингэснээр л амь зан чанарт чинь өөрчлөлт гарна, энэ замаар л чи Бурханаар төгс болгуулж чадна, ийм маягаар Бурханаар төгс болгуулсан хүмүүс л Түүний хүсэлтэй нийцэж чадна. Шинэ гэрлийг хүлээн авахын тулд чи Түүний үгэн дотор амьдрах ёстой. Ганцхан удаа Ариун Сүнсээр хөдөлгөгдөх нь ямар ч нэмэргүй—чи илүү гүн рүү орох ёстой. Ганцхан удаа сэтгэл нь хөдөлсөн хүмүүсийн дотор урам зориг төрж, эрж хайх хүсэлтэй болдог ч энэ нь удаан үргэлжилж чаддаггүй; Ариун Сүнс тэдний сэтгэлийг байнга хөдөлгөх ёстой байдаг. Бурханы Сүнс хүмүүсийн сүнсийг хөдөлгөснөөр хүмүүс амь зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх байх, мөн Бурханаар сэтгэлээ хөдөлгүүлэхээр зорих зуураа хангалтгүй байдлаа ойлгож, Түүний үгийг туулах явцдаа өөрсдийнхөө доторх бохир зүйлсийг (өөрийгөө зөвтгөх байдал, биеэ тоосон зан, үзэл гэх мэт) хаях байх гэж найддаг гэдгээ Би урьд нь маш олон удаа дурдаж байсан. Шинэ гэрлийг идэвх санаачилгатайгаар хүлээн авах нь л хангалттай гэж бүү бод—чи бас сөрөг бүхнийг хаях ёстой. Нэг талаар, та нар эерэг талаас орох хэрэгтэй, нөгөөтээгүүр, сөрөг талын бүх бохир зүйлээс ангижрах хэрэгтэй. Дотор чинь ямар бохир зүйл оршсоор байгаа эсэхийг харахын тулд өөрийгөө байнга шалгах ёстой. Хүмүүсийн шашны үзэл, санаа зорилго, итгэл найдвар, өөрийгөө зөвтгөх байдал, биеэ тоосон зан бол бүгд бохир зүйл юм. Шашны ямар үзэлтэйгээ харахын тулд өөрийнхөө доторхыг шинжилж, илчлэлийн талаарх Бурханы бүх үгтэй харьцуулан жиш. Тэдгээрийг үнэхээр танин мэдэх үедээ л чи хаяж чадна. Зарим хүн: “Ариун Сүнсний өнөөгийн ажлын гэрлийг дагахад л одоо хангалттай. Өөр юунд ч санаа зовох хэрэггүй” гэж хэлдэг. Тэгвэл шашны үзлүүд чинь гарч ирэх үед чи яаж тэдгээрээс ангижрах вэ? Бурханы өнөөдрийн үгийг дагах нь энгийн зүйл гэж чи бодож байна уу? Хэрвээ чи шашны хүн мөн бол зүрх сэтгэлд чинь байдаг шашны үзэл, шашин судлалын уламжлалт онол саад учруулж болох бөгөөд эдгээр зүйл гарч ирэх үедээ шинэ зүйлсийг хүлээн авахад чинь саад болдог. Эдгээр нь бүгд бодит асуудал юм. Хэрвээ чи Ариун Сүнсний одоогийн үгийг л эрэлхийлдэг бол Бурханы хүслийг биелүүлж чадахгүй. Ариун Сүнсний өнөөгийн гэрлийг эрэлхийлэхийн зэрэгцээ чи ямар үзэл, санаа зорилго өвөрлөдгөө, өөрийгөө зөвтгөдөг ямар зан чамд байгааг, ямар зан авир чинь Бурханд дуулгавартай бус байдгийг танин мэдэх ёстой. Энэ бүх зүйлийг танин мэдсэнийхээ дараа чи тэдгээрийг хаях ёстой. Урьдын үйлдэл, зан авирыг чинь орхиулах нь бүхэлдээ Ариун Сүнсний өнөөдөр ярьдаг үгийг дагах боломжийг чамд олгохын төлөө байдаг. Зан чанарын өөрчлөлтөд нэг талаас Бурханы үгээр дамжуулан хүрдэг, нөгөө талаас хүмүүс хамтран ажиллах шаардлагатай байдаг. Үүнд Бурханы ажил болон хүний хэрэгжүүлэлт хоёулаа зайлшгүй шаардлагатай.

Ирээдүйн үйлчлэлийн замдаа чи Бурханы хүслийг хэрхэн биелүүлж чадах вэ? Нэг чухал зүйл бол амийн оролтыг эрэлхийлэх, зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх, үнэнд илүү гүн гүнзгий орохоор эрэлхийлэх явдал юм—энэ бол Бурханаар төгс болгуулж, авхуулах зам билээ. Та нар бүгд Бурханы даалгаврыг хүлээн авагч, гэхдээ ямар төрлийн даалгавар вэ? Энэ нь ажлын дараагийн алхамтай холбоотой байдаг; ажлын дараагийн алхам нь бүх орчлон ертөнц даяар хэрэгждэг илүү агуу ажил байх болно. Тиймээс та нар өнөөдөр амь зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх ёстой, ингэснээр ирээдүйд та нар Өөрийн ажлаар дамжуулан Бурхан алдрыг олж авахын жинхэнэ нотолгоо болж, Түүний ирээдүйн ажлын үлгэр жишээ болж магадгүй. Өнөөдрийн эрэл хайгуул тэр чигтээ ирээдүйн ажлын суурийг тавихын төлөө байдаг, мөн Бурханаар ашиглагдаж, Түүнд гэрчлэл хийж чадахын төлөө байдаг. Хэрвээ чи үүнийг эрэл хайгуулынхаа зорилго болговол Ариун Сүнсний өмнө байж чадна. Эрэл хайгуулдаа өндөр зорилго тавих тусам чи төдий чинээ төгс болгуулж чадна. Үнэнийг хэдий чинээ их эрэлхийлнэ, Ариун Сүнс төдий чинээ их ажилладаг. Эрэл хайгуулдаа эрч хүчээ зориулах тусам чи төдий чинээ ихийг олж авна. Ариун Сүнс хүмүүсийг дотоод байр байдлынх нь дагуу төгс болгодог. Зарим хүн, Бурханд ашиглагдахыг, эсвэл Түүгээр төгс болгуулахыг хүсэхгүй байна, зүгээр л махан бие нь эсэн мэнд байж, ямар ч золгүй явдал амсахгүй байхыг хүсэж байна гэж хэлдэг. Зарим хүн хаанчлалд орохыг хүсдэггүй мөртөө ёроолгүй нүхэнд унахыг хүсдэг. Тэр тохиолдолд Бурхан хүслийг чинь бас биелүүлж өгнө. Чи юу ч эрэлхийлдэг бай, Бурхан биелүүлнэ. Тэгвэл чи одоо юу эрэлхийлж байна вэ? Төгс болгуулахыг уу? Одоогийн үйлдэл, зан авир чинь Бурханаар төгс болгуулж, Түүгээр авхуулахын төлөө байдаг уу? Чи өдөр тутмын амьдралдаа өөрийгөө байнга ингэж цэгнэх ёстой. Хэрэв чи ганцхан зорилгыг эрэлхийлэхэд зүрх сэтгэлээ бүрэн зориулдаг бол Бурхан чамайг гарцаагүй төгс болгоно. Энэ бол Ариун Сүнсний зам юм. Ариун Сүнс хүмүүсийг залж чиглүүлдэг замд хүмүүсийн эрэл хайгуулаар хүрдэг. Чи Бурханаар төгс болгуулж, авхуулахыг хэдий чинээ их хүсэн тэмүүлнэ, Ариун Сүнс чиний дотор төдий чинээ их ажиллана. Эрж хайж чадахгүй байх тусмаа чи улам сөрөг болж, ухарч буцдаг ба Ариун Сүнсний ажиллах боломж төдий чинээ үгүй болдог; цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Ариун Сүнс чамайг орхино. Чи Бурханаар төгс болгуулахыг хүсэж байна уу? Бурханаар авхуулахыг хүсэж байна уу? Бурханд ашиглагдахыг хүсэж байна уу? Бурханы үйлдэл та нараар илэрхийлэгдсэнийг орчлон ертөнц болон бүх зүйлд харуулахын тулд та нар Бурханаар төгс болгуулж, авхуулж, ашиглуулахын төлөө бүхнийг хийхээр хичээх ёстой. Оршин байгаа бүхний дундаас, та нар бол бүх зүйлийн эзэн, та нар өөрсдөөрөө дамжуулан гэрчлэл болон алдар сууг Бурханд эдлүүлнэ—энэ нь, хамгийн их ерөөгдсөн үеийнхэн гэдгийн чинь нотолгоо юм!

БУРХАНЫ ӨМНӨ ЗҮРХ СЭТГЭЛЭЭ ТАЙВАН БАЙЛГАХ ТУХАЙ

Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгах нь Бурханы үгэнд орох хамгийн чухал алхам юм. Одоо хүн бүр энэ хичээлд яаралтай орох хэрэгтэй. Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгахад дараах замаар орно:

1. Гаднах хэрэг явдлаас сэтгэлээ тат. Бурханы өмнө тайван байж, Бурханд залбирахад хамаг анхаарлаа хандуул.
2. Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж, Бурханы үгийг идэж ууж, эдэл.
3. Сэтгэлдээ Бурханы хайрыг бясалгаж, эргэцүүлж, Бурханы ажлыг тунгаа.

Нэгдүгээрт, залбирлын талаас эхэл. Тогтсон цагт нэгэн үзүүрт сэтгэлээр залбир. Цаг хэчнээн давчуу, ажил хэчнээн завгүй байлаа ч, чамд юу ч тохиолдлоо гэсэн өдөр бүр хэвийн байдлаар залбирч, Бурханы үгийг хэвийн байдлаар идэж уу. Ямар ч орчинд бай, Бурханы үгийг идэж ууж байгаа цагт сүнс чинь асар их таашаал авах бөгөөд эргэн тойрны хүмүүс, үйл явдал, юмсын нөлөөнд автахгүй. Ерөнхийдөө Бурханыг сэтгэлдээ бодох үед гадна болж байгаа зүйл төвөг болж чадахгүй. Биеийн хэмжээтэй байх гэдэг нь энэ юм. Залбирлаас эхэл: Бурханы өмнө тайван залбирах нь хамгийн үр өгөөжтэй. Үүний дараа Бурханы үгийг идэж ууж, Бурханы үгийг тунгаах замаар тэдгээрийн доторх гэрлийг эрж хайж, хэрэгжүүлэлтийн замыг олж, Бурханы үг хэлдэг зорилгыг мэдэж, тэдгээрийг ямар ч гажуудалгүйгээр ойлго. Ер нь гаднах зүйлд сатааралгүйгээр сэтгэлдээ Бурханд ойртож, Бурханы хайрыг эргэцүүлж, Бурханы үгийг тунгааж чадна гэдэг чиний хувьд хэвийн зүйл байх ёстой. Сэтгэл чинь тодорхой хэмжээнд тайвшрах үед чимээгүйхэн бодолхийлж чадаж, ямар ч орчинд дотроо Бурханы хайрыг эргэцүүлж, Түүнд үнэхээр ойртон, эцэстээ сэтгэлд чинь магтаал хурах бөгөөд ингэх нь залбирлаас ч дээр юм. Тэр үед чи тодорхой биеийн хэмжээтэй болно. Хэрвээ чи дээр тодорхойлсон төлөвт хүрч чадвал зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үнэхээр тайван байгааг нотолно. Эхний үндсэн хичээл энэ юм. Хүмүүсийг Бурханы өмнө тайван байж чаддаг болсных нь дараа л Ариун Сүнс хөдөлгөж, гэгээрүүлж, гэрэлтүүлж чадах бөгөөд ингэснээр л Бурхантай жинхэнээсээ ярилцаж, Бурханы хүсэл болон Ариун Сүнсний удирдамжийг ухаарч чадна. Дараа нь тэд сүнслэг амьдралын зөв замд орсон байх болно. Бурханы өмнө амьдрах сургалтаа тодорхой гүнд хүргэж, өөрсдийгөө хаяж, үзэн ядаж, Бурханы үгэнд амьдарч чаддаг болох үедээ тэд Бурханы өмнө зүрх сэтгэлээ үнэхээр тайван байлгасан байна. Хүмүүс өөрийгөө үзэн ядаж, харааж, хаяж чадаж байх нь Бурханы ажлын хүрсэн үр дүн бөгөөд тэд өөрсдөө ингэж чаддаггүй. Тиймээс Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгах хэрэгжүүлэлт нь хүмүүсийн нэн даруй орох ёстой хичээл юм. Зарим хүн Бурханы өмнө ихэвчлэн тайван байж чаддаггүйгээс гадна залбирч байхдаа ч Бурханы өмнө сэтгэлдээ тайван байж чаддаггүй. Ингэх нь Бурханы стандартад огт нийцэхгүй! Бурханы өмнө сэтгэлдээ тайван байх чадваргүй хүнийг Ариун Сүнс хөдөлгөж чадах уу? Хэрвээ чи Бурханы

өмнө тайван байж чаддаггүй бол хүн ирэх үед, эсвэл бусдыг ярих үед анхаарал чинь сарних эрсдэлтэй бөгөөд бусдыг юм хийж байхад сэтгэл чинь бэлчих боломжтой, ингэсэн тохиолдолд чи Бурханы өмнө амьдрахгүй. Бурханы өмнө зүрх сэтгэл чинь үнэхээр тайван байдаг бол гаднын ертөнцөд болж байгаа ямар ч зүйлд сатаарахгүй, ямар ч хүн, үйл явдал, юманд эзэмдүүлэхгүй. Үүнд орох юм бол хүний идэвхгүй байдал эсвэл хүний үзэл, амьдралын гүн ухаан, хүмүүсийн хоорондох хэвийн бус харилцаа, санаа, бодол гэх мэт тэр бүх сөрөг зүйл аяндаа арилна. Чи Бурханы үгийг үргэлж тунгаан, сэтгэлдээ Бурханд үргэлж ойртож, Бурханы одоогийн үгэнд үргэлж эзэмдүүлдэг учраас тэдгээр сөрөг зүйл нэг л мэдэхэд чамайг орхино. Шинэ, эерэг зүйл чамайг эзэмдэх үед сөрөг хуучин зүйл байх газаргүй болох тул тэрхүү сөрөг зүйлсэд анхаарал бүү хандуул. Чи тэдгээрийг хянахын тулд хичээл зүтгэл гаргах хэрэггүй. Бурхан одоо хүнийг биечлэн төгс болгож, зүрх сэтгэлийг чинь олж авахыг хүсэж байгаа тул Бурханы өмнө тайван байж, Бурханы үгийг чадлынхаа хэрээр идэж ууж, эдэлж, Бурханыг магтсан магтан дууг чадах чинээгээрээ их дуулж, чам дээр ажиллах боломжийг Бурханд олгох ёстой. Түүний Сүнс зүрх сэтгэлийг чинь хөдөлгөдөг бөгөөд хэрэв чи Ариун Сүнсний удирдамжийг даган Бурханы өмнө амьдардаг болбол Бурханыг хангалуун байлгана. Хэрвээ чи Бурханы үгэнд амьдрахад анхаарч, үнэний тухай илүү их нөхөрлөж, Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг олж авах юм бол шашны тэдгээр үзэл, өөрийгөө зөвтгөж, чухалчлах байдал чинь бүгд алга болоод, Бурханы төлөө өөрийгөө хэрхэн зарлагадах, Бурханыг хэрхэн хайрлаж, хангалуун болгохоо мэднэ. Тэгээд Бурхантай холбоогүй зүйлс нэг л мэдэхэд ухамсраас чинь бүрмөсөн арилна.

Бурханы одоогийн үгийг идэж, уух зууraa үгийг нь тунгаан бодож, залбирах нь Бурханы өмнө амар тайван байх эхний алхам билээ. Хэрвээ чи Бурханы өмнө үнэхээр тайван байж чаддаг бол Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт чамтай хамт байх болно. Бурханы өмнө тайван байснаар бүх сүнслэг амьдрал биелдэг. Залбирахдаа чи Бурханы өмнө тайван байх ёстой, тэр үед л Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөж чадна. Бурханы үгийг идэж, уугаад Бурханы өмнө тайван байх үедээ чи гэгээрч, гэрэлтүүлэгдэж чадах бөгөөд Бурханы үгийг үнэхээр ойлгож чадна. Ердийн эргэцүүлэл, нөхөрлөлийн үйл ажиллагаандаа зүрх сэтгэлээрээ Бурханд ойртохдоо Бурханы өмнө тайван болж, Бурханд жинхэнээсээ ойр дотно болж, Бурханы хайр, Бурханы ажлыг жинхэнээсээ ойлгож, Бурханы санаа зорилгыг үнэхээр хайхарч, анхаарч чадна. Ердийн үед Бурханы өмнө тайван байж чаддаг байх тусмаа чи төдий чинээ гэрэлтүүлэгдэнэ, мөн завхарсан зан чанараа, чамд дутагддаг зүйл юу байдгийг, юунд орох ёстойгоо, ямар чиг үүрэг гүйцэтгэх ёстойгоо, өө сэв чинь хаана оршдогийг төдий чинээ мэдэж чадна. Бурханы өмнө тайван байснаар энэ бүхэн биелдэг. Хэрвээ чи Бурханы өмнө үнэхээр гүнээ тайван байдаг бол сүнсэн дэх нууцуудыг ухаарч, Бурхан одоо чам дээр юу хийхийг хүсдэгийг ухаарч, Бурханы үгийг илүү гүн гүнзгий ойлгож, Бурханы үгийн гол утга, Бурханы үгийн мөн чанар, Бурханы үгийн оршихуйг ухаарч чадах бөгөөд хэрэгжүүлэлтийн

замыг илүү тодорхой, нарийн зөв харж чадна. Хэрвээ чи хангалттай хэмжээнд сүнсээрээ тайван байж чадахгүй бол Ариун Сүнс чиний сэтгэлийг жаахан л хөдөлгөнө; дотроо хүчирхэгжсэн мэт чамд санагдаж, тодорхой хэмжээний таашаал, амар тайвныг мэдрэх боловч илүү гүн юуг ч ухаарахгүй. Би өмнө нь ингэж хэлсэн: Хэрвээ хүн бүх хүч чадлаа ашигладаггүй бол Миний дуу хоолойг сонсох юм уу, Миний царайг харахад хэцүү байх болно. Энэ нь Бурханы өмнө өнгөц хүчин чармайлт гаргахыг биш, харин гүнээ тайван байхыг хэлдэг. Бурханы өмнө үнэхээр амар тайван байж чаддаг хүн өөрийгөө дэлхий ертөнцийн бүх хүлээсээс чөлөөлж, Бурханаар эзэмдүүлж чаддаг. Бурханы өмнө тайван байж чаддаггүй бүх хүн гарцаагүй цадиггүй, дур зоргоороо байдаг. Бурханы өмнө тайван байх чадвартай бүх хүн бол Бурханы өмнө үнэн сүсэгтэй байдаг, Бурханыг хүсэн эрмэлздэг хүмүүс юм. Бурханы өмнө тайван байдаг хүмүүс л амийг үнэлж, сүнсээр нөхөрлөхийг үнэлж, Бурханы үгээр цангаж, үнэнийг эрэлхийлдэг. Бурханы өмнө амар тайван байхыг үнэлдэггүй, Бурханы өмнө тайван байх явдлыг хэрэгжүүлдэггүй хэн боловч нэрэлхүү, өнгөцхөн бөгөөд дэлхий ертөнцөд татагддаг, амьгүй билээ; тэр Бурханд итгэдэг гэж хэлдэг ч гэсэн ердөө л дүр эсгэж байгаа юм. Эцэстээ Бурханы төгс болгож, бүрэн гүйцэд болгодог хүмүүс нь Түүний өмнө тайван байж чаддаг хүмүүс мөн. Тиймээс Бурханы өмнө тайван байдаг хүмүүс агуу ерөөлөөр ивээгддэг. Бурханы үгийг идэж, уухад өдөртөө хомсхон цаг гаргадаг хүмүүс, гаднын хэрэг явдалд завгүй автаж, амийн оролтыг чухалчилдаггүй хүмүүс—эдгээр нь бүгд өсөх ирээдүйгүй хоёр нүүртнүүд юм. Бурханы өмнө тайван байж чаддаг, Бурхантай жинхэнээсээ ярилцаж чаддаг хүмүүс бол Бурханы ард билээ.

Бурханы өмнө ирж Түүний үгийг амиа болгон хүлээн зөвшөөрөхийн тулд чи эхлээд Бурханы өмнө тайван байх ёстой. Бурханы өмнө тайван байх үед чинь л Бурхан чамайг гэгээрүүлж, чамд мэдлэг өгнө. Хүмүүс Бурханы өмнө тайван байх тусмаа Бурханы гэгээрэл, гэрэлтүүлэлтийг төдий чинээ их хүлээн авч чаддаг. Энэ бүхэн нь хүмүүсээс чин сүсэгтэй, итгэлтэй байхыг шаарддаг; тэгж байж л тэд төгс болгуулж чадна. Сүнслэг амьдралд орох үндсэн гол хичээл бол Бурханы өмнө тайван байх явдал билээ. Бурханы өмнө тайван байснаар л сүнслэг бүх сургалт чинь үр ашигтай байх болно. Хэрвээ зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байж чадахгүй бол чи Ариун Сүнсний ажлыг хүлээн авч чадахгүй. Юу ч хийж байсан хамаагүй, зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байдаг бол чи Бурханы өмнө амьдардаг хүн юм. Юу ч хийж бай хамаагүй, зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байж, Бурханд ойртдог бол Бурханы өмнө тайван байдаг хүн мөн гэдгийг чинь энэ нь баталдаг. Хэрвээ бусадтай ярьж юм уу, алхаж байх үедээ “Зүрх сэтгэл минь Бурханд ойртож байгаа ба гаднын зүйлсэд төвлөрдөггүй, бас би Бурханы өмнө тайван байж чадна” хэмээн хэлж чаддаг бол чи Бурханы өмнө тайван байдаг хүн мөн. Зүрх сэтгэлийг чинь гаднын хэрэг явдал руу татдаг ямарваа зүйлтэй, эсвэл зүрх сэтгэлийг чинь Бурханаас салгадаг хүмүүстэй бүү холбогд. Зүрх сэтгэл чинь Бурхантай ойр дотно байхад саад болдог юуг ч бай хойш тавьж, түүнээс хол бай.

Энэ нь аминд чинь илүү их ач тустай. Одоо үе бол яг нарийндаа Ариун Сүнсний агуу ажлын цаг үе, Бурхан хүмүүсийг биечлэн төгс болгодог цаг үе билээ. Хэрвээ энэ мөчид чи Бурханы өмнө тайван байж чаддаггүй бол Бурханы сэнтийн өмнө буцаж очих хүн биш юм. Хэрвээ чи Бурханыг бус өөр зүйл эрэлхийлдэг бол Бурханаар төгс болгуулах ямар ч аргагүй байх болно. Өнөөдөр Бурханаас ийм айлдваруудыг сонсож чаддаг атлаа Түүний өмнө тайван байж чаддаггүй хүмүүс бол үнэнийг хайрладаггүй, Бурханыг хайрладаггүй хүмүүс мөн. Хэрвээ чи энэ мөчид өөрийгөө өргөн барихгүй юм бол юу хүлээгээд байгаа юм бэ? Өөрийгөө өргөн барих гэдэг нь Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгах явдал билээ. Тэр нь жинхэнэ өргөл байх юм. Одоо зүрх сэтгэлээ Бурханд үнэхээр өргөн барьдаг хэн боловч Бурханаар бүрэн төгс болгуулах нь лавтай. Юу ч байлаа гэсэн, чамайг үймүүлж чадахгүй; чамайг засах ч бай, чамтай харьцах ч бай, эсвэл чи урагшгүйтэл, бүтэлгүйтэлтэй тулгарсан ч бай, зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван байх ёстой. Хүмүүс чамд яаж хандах нь хамаагүй, зүрх сэтгэл чинь Бурханы өмнө тайван байх ёстой. Чамд ямар ч нөхцөл байдал тулгарсан бай хамаагүй—гай гамшиг, зовлон, хавчлага юм уу, өөр өөр шалгалт хүрээлсэн ч бай хамаагүй—зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван байх ёстой; эдгээр нь төгс болгох зам юм. Бурханы өмнө үнэхээр тайван байдаг нэгэнд л Бурханы одоогийн үг тодорхой болно. Тэгээд чи Ариун Сүнсний гэрэлтүүлэлт, гэгээрлээс гажилгүй илүү зөв хэрэгжүүлж, үйлчлэлд чинь илүү тодорхой чиглэл өгөх Бурханы санаа зорилгыг улам тодорхой ухаарч, Ариун Сүнсний хөдөлгөлт, удирдамжийг илүү нарийн зөв ухаарч, Ариун Сүнсний удирдамж дор амьдрахдаа итгэлтэй байж чадна. Энэ нь Бурханы өмнө үнэхээр тайван байснаар хүрдэг үр дүн билээ. Зүрх сэтгэл нь Бурханы өмнө тайван байдаггүйгээс болж хүмүүс Бурханы үгийг тодорхой ойлгодоггүй, хэрэгжүүлэлтийн ямар ч замгүй, Бурханы хүслийг ухаарч чаддаггүй, эсвэл хэрэгжүүлэлтийн зарчмаар дутагддаг. Бурханы өмнө тайван байх зорилго нь Бурханы үгээс нухацтай, прагматик, үнэн зөв, ил тод байдлыг эрж хайж, эцэстээ үнэнийг ойлгож, Бурханыг мэдэх явдал юм.

Хэрвээ зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван байдаггүй бол чамайг төгс болгох арга Бурханд үгүй. Шийдвэргүй байна гэдэг зүрх сэтгэлгүй байхтай эн тэнцүү бөгөөд зүрх сэтгэлгүй хүн Бурханы өмнө тайван байж чадахгүй; ийм хүн Бурхан хэр их ажил хийдгийг, хэр их үг хэлдгийг мэддэггүй, хэрхэн хэрэгжүүлэхээ ч мэддэггүй. Энэ чинь зүрх сэтгэлгүй хүн биш гэж үү? Зүрх сэтгэлгүй хүн Бурханы өмнө тайван байж чадах уу? Зүрх сэтгэлгүй хүмүүсийг төгс болгох ямар ч арга Бурханд байдаггүй—тэд адгуус амьтнаас өөрцгүй. Бурхан маш тодорхой, ил тод ярьсан атал зүрх сэтгэл чинь хөдлөлгүй, Бурханы өмнө тайван байх чадваргүй хэвээр үлддэг. Чи адгуус амьтан биш үү? Зарим хүн Бурханы өмнө тайван байхаар хэрэгжүүлэх үедээ замаасаа гаждаг. Хоол хийх цаг болоход тэд хоол хийдэггүй, гэр орны ажил хийх цаг болоход хийдэггүй, харин зүгээр л залбирч, тунгаан бодсоор байдаг. Бурханы өмнө тайван байх гэдэг нь хоол хийхгүй, гэр орны ажил хийхгүй

юм уу, аж амьдралаа мартана гэсэн үг биш; харин ч аливаа хэвийн байдалд Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж, Бурханд зориулсан орон зайг зүрх сэтгэлдээ байлгаж чадна гэсэн үг юм. Залбирах үедээ чи Бурханы өмнө зохих ёсоор сөхөрч залбирах ёстой; гэр орны ажил хийх юм уу хоол хийх үедээ Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж, Бурханы үгийг тунгааж, эсвэл магтан дуу дуул. Чи ямар ч нөхцөл байдалд байсан бай, өөрийн гэсэн хэрэгжүүлэлтийн арга замтай байж, Бурханд ойртохын тулд чадах бүхнээ хийх ёстой бөгөөд Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгахын тулд бүх чадлаараа хичээх хэрэгтэй. Боломж олдох үед нэгэн үзүүрт сэтгэлээр залбир; боломж олдохгүй бол урдах ажлаа хийх зуураа зүрх сэтгэлдээ Бурхантай ойрт. Бурханы үгийг идэж, ууж чадах үедээ идэж, уу; залбирч чадах үедээ залбир; Бурханыг дурсах үедээ дурсан бод. Өөрөөр хэлбэл, оролтод өөрийгөө дадлагажуулахын тулд орчиндоо нийцүүлэн чадах бүхнээ хий. Ямар ч асуудалгүй байх үед зарим хүн Бурханы өмнө тайван байж чаддаг боловч ямар нэг зүйл тохиолдмогц оюун санаа нь самуурдаг. Тэр нь Бурханы өмнө тайван байгаа хэрэг биш юм. Туршлагажих зөв зам бол ямар ч нөхцөл байдалд хүний зүрх сэтгэл Бурханаас холдохгүй, эсвэл гаднын хүмүүс, хэрэг явдал, юмсаас болж сатаарахгүй байх явдал бөгөөд ийм хүн л Бурханы өмнө үнэхээр тайван байдаг хүн мөн. Цугларалтын үеэр залбирахдаа зүрх сэтгэл нь Бурханы өмнө тайван байж чаддаг боловч бусадтай нөхөрлөхдөө Бурханы өмнө тайван байж чадахгүй, бодол нь зоргоороо хадуурдаг гэж зарим хүн хэлдэг. Энэ нь Бурханы өмнө тайван байгаа хэрэг биш. Өнөөдөр ихэнх хүн ийм байдалд байдаг бөгөөд зүрх сэтгэл нь Бурханы өмнө үргэлж тайван байж чаддаггүй. Тиймээс та нар энэ талаар өөрсдийгөө дадлагажуулахад илүү их хичээл чармайлт гаргаж, амийн туршлагын зөв замд алхам алхмаар орж, Бурханаар төгс болгуулах замаар явж эхлэх ёстой.

ТӨГС ТӨГӨЛДӨРТ ХҮРЭХИЙН ТУЛД БУРХАНЫ ХҮСЛИЙГ АНХААР

Чи Бурханы хүслийг хэдий чинээ анхаарна, төдий чинээ их ачаа үүрнэ, үүрдэг ачаа чинь их байх тусам, туршлага чинь төдий чинээ баялаг байна. Бурханы хүслийг анхаарах үед чинь Бурхан чамд ачаа үүрүүлж, дараа нь чамд даалгасан даалгаврынхаа талаар чамайг гэгээрүүлнэ. Бурхан чамд энэхүү ачааг өгөхөд чи Бурханы үгийг идэж, ууж байхдаа холбогдох бүх үнэнд анхаарлаа хандуулна. Хэрвээ чи ах, эгч нарынхаа амийн байр байдалтай хамаатай ачаа үүрдэг бол тэр нь Бурханаас чамд даалгасан ачаа бөгөөд чи өдөр тутмынхаа залбиралд энэхүү ачааг байнга үүрнэ. Бурханы хийдэг зүйлийг чамд үүрүүлсэн бөгөөд Бурханы хийхийг хүсдэг зүйлийг чи хийхийг хүсэж байгаа; Бурханы ачааг өөрийн мэт хүлээж авах гэдэг нь энэ юм. Энэ үед Бурханы үгийг идэж ууж байхдаа чи энэ төрлийн асуудалд анхаарлаа төвлөрүүлж, “Эдгээр асуудлыг би хэрхэн шийдвэрлэх вэ?

Чөлөөлөлтөд хүрч, сүнслэг таашаал эдлэх боломжийг ах эгч нартаа хэрхэн олгох вэ?” гэж бодно. Чи нөхөрлөж байхдаа эдгээр асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа төвлөрүүлэх бөгөөд Бурханы үгийг идэж, ууж байхдаа эдгээр асуудалтай холбоотой үгийг идэж, уухад анхаарлаа төвлөрүүлнэ. Бурханы үгийг идэж, ууж байхдаа ч бас ачаа үүрнэ. Чи Бурханы шаардлагыг ойлгомогцоо аль замыг сонгох талаар илүү тодорхой бодол санаатай болно. Энэ нь чиний ачаагаар дамжин ирсэн Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт бөгөөд энэ нь бас чамд хайрласан Бурханы удирдамж юм. Би яагаад үүнийг хэлж байна вэ? Хэрвээ чамд ямар ч ачаа байхгүй бол Бурханы үгийг идэж, ууж байхдаа чи анхааралтай байхгүй; ачаа үүрэнгээ Бурханы үгийг ууж, идэх үедээ чи мөн чанарыг нь ухаарч, замаа олж, Бурханы хүслийг анхаарч чадна. Тиймээс залбиралдаа чи, Бурхан чамд илүү их ачаа үүрүүлж, илүү их үүрэг даалгавар даалгаасай гэж хүсэх хэрэгтэй, ингэснээр өмнө чинь хэрэгжүүлэх илүү их зам байж болох юм; мөн ингэснээр Бурханы үгийг идэж, уух чинь илүү их үр нөлөөтэй байж, Бурханы үгийн мөн чанарыг ухаарч чаддаг болж, Ариун Сүнсээр илүү их хөдөлгөгдөх чадвартай болно.

Бурханы үгийг идэж, уух, залбирал үйлдэх, Бурханы ачааг хүлээн авах, Түүний даалгасан даалгаврыг хүлээн авах—энэ бүхэн нь чамайг өмнөө замтай байлгахын төлөө байдаг. Чамд Бурханы даалгасан ачаа хүнд байх тусам Бурханаар төгс болгуулахад илүү амархан байх болно. Зарим хүн дуудлага авсан ч гэсэн Бурханд үйлчлэхдээ бусадтай хамтран ажиллахыг хүсдэггүй; тэд бол зөвхөн тав тухтай байдалд умбахыг хүсдэг залхуу хүмүүс юм. Бусадтай хамтран үйлчлэхийг чамаас шаардах тусам чи илүү их туршлага хуримтлуулна. Илүү их ачаа, туршлагатай байснаар чи төгс болгуулах илүү их боломжтой болно. Тиймээс хэрвээ чи Бурханд чин сэтгэлээсээ үйлчилж чадвал Бурханы ачааг анзаарна; тийм болохоор Бурханаар төгс болгуулах илүү их боломжтой болно. Ийм бүлэг хүмүүс л одоогоор төгс болгуулж байгаа. Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөх тусам, чи Бурханы ачааг анзаарахад илүү их цаг зориулж, Бурханаар илүү их төгс болгуулж, Бурханаар илүү их авхуулна—тэгээд эцэст нь чи Бурханы ашигладаг хүн болно. Одоогоор чуулганы төлөө ямар ч ачаа үүрдэггүй зарим хүн байдаг. Энэ хүмүүс хойрго, назгай бөгөөд махан биеэ л хайхардаг. Ийм хүмүүс туйлын аминч, маш харалган байдаг. Чи энэ асуудлыг тодорхой харж чадахгүй бол ямар ч ачаа үүрэхгүй. Чи Бурханы хүслийг анзаарах тусам Бурхан чамд илүү их ачаа даалгана. Аминчхан хүмүүс тийм зүйл амсахыг хүсдэггүй; төлөөс төлөхийг хүсдэггүй бөгөөд үүний үр дүнд Бурханаар төгс болгуулах боломжоо алдана. Тэд өөрсдийгөө хорлож байгаа бус уу? Чи Бурханы хүслийг анхаардаг нэгэн бол чуулганы төлөө жинхэнэ ачаатай болно. Үнэн хэрэгтээ, үүнийг чуулганы төлөө үүрдэг ачаа гэхийн оронд амийнхаа төлөө үүрдэг ачаа гэж нэрлэвэл илүү зохилтой, учир нь чуулганы төлөө бий болгодог энэ ачааны чинь зорилго нь ийм туршлага ашиглан Бурханаар төгс болгуулах явдал юм. Тиймээс чуулганы төлөө хамгийн их ачаа үүрдэг хэн боловч, мөн амь руу орохдоо ачаа үүрдэг хэн боловч Бурханаар төгс болгуулдаг хүмүүс

байх болно. Чи үүнийг тодорхой харсан уу? Чиний байгаа чуулган элс шиг тархай бутархай боловч чи үүнд санаа зовдог ч үгүй, түгшдэг ч үгүй бол, мөн ах, эгч нар чинь Бурханы үгийг хэвийн байдлаар идэж, уухгүй байгааг хараагүй царайлдаг бол чи ямар ч ачаа үүрээгүй байна. Ийм хүмүүс бол Бурханы баярлан бахаддаг төрлийн хүмүүс биш юм. Бурханы баярлан бахаддаг төрлийн хүмүүс зөв шударга байдлаар өлсөж, цангадаг бөгөөд Бурханы хүслийг анхаардаг. Тиймээс та нар одоо Бурханы ачааг анхаардаг болох ёстой; Бурханы ачааг анхаардаг болохоосоо өмнө чи Бурхан зөвт зан чанараа бүх хүн төрөлхтөнд илчлэхийг хүлээх ёсгүй. Тэр үед хэтэрхий оройтсон байх бус уу? Одоо үе бол Бурханаар төгс болгуулах сайхан боломж юм. Хэрвээ чи энэ боломжийг алдвал, Мосе Канааны сайхан нутагт орж чадалгүй, насан туршдаа харамсаж, харуусалтайгаар нас эцэслэсэн шиг үлдсэн амьдралынхаа турш үүндээ харамсана. Бурхан бүх хүнд Өөрийн зөвт зан чанарыг илчилмэгц чи харууслаар дүүрнэ. Бурхан чамайг гэсгээдэггүй ч гэсэн, чи харууссанаасаа болж өөрийгөө гэсгээнэ. Зарим хүн үүнд үнэмшдэггүй боловч хэрвээ чи итгэхгүй байгаа бол зүгээр л хүлээгээд харзна. Эдгээр үгийг хэрэгжүүлэх цор ганц зорилготой зарим хүн байдаг. Харин чи эдгээр үгийн төлөө өөрийгөө золиослохыг хүсэж байна уу?

Хэрвээ чи Бурханаар төгс болгуулах боломжийг эрж хайдаггүй бол, мөн төгс төгөлдрийг эрж хайхдаа бусдаас урьтахаар чармайдаггүй бол эцэстээ харууслаар дүүрнэ. Төгс болгуулах хамгийн сайхан боломж одоо байна; одоо бол туйлын сайхан цаг. Чи Бурханаар төгс болгуулахаар үнэн сэтгэлээсээ эрэлхийлдэггүй бол Түүний ажил дуусмагц хэтэрхий оройтсон байх болно—чи боломжоо алдсан байх болно. Чиний хүсэл эрмэлзэл хэчнээн их байсан ч Бурхан ажлаа гүйцэтгэхээ болих юм бол хэчнээн их хүчин чармайлт гаргаад ч хэзээ ч төгс болгуулж чадахгүй. Ариун Сүнсийг асар ихээр ажиллаж байхад чи энэ боломжийг ашиглаж, хамтран ажиллах ёстой. Хэрэв энэ боломжийг алдвал ямар ч хүчин чармайлт гаргасан бай, чамд дахиад өөр боломж олгохгүй. Зарим нэг чинь: “Бурхан минь, би Таны ачааг анхаарахыг хүсэж байна, Таны хүслийг хангахыг хүсэж байна!” гэж хашхирдаг. Гэвч чамд хэрэгжүүлэх ямар ч зам байдаггүй тул ачаа чинь удаан үргэлжлэхгүй. Харин урд чинь зам байвал чи алхам алхмаар туршлага хуримтлуулах бөгөөд туршлага чинь зохион байгуулалттай, эмх цэгцтэй байна. Нэг ачааг дуусгасны дараа чамд өөр нэг ачаа өгнө. Амийн туршлага чинь гүнзгийрэх тусам ачаа чинь ч илүү гүн гүнзгий болно. Зарим хүн Ариун Сүнс сэтгэлийг нь хөдөлгөх үед л ачаа үүрдэг; хэсэг хугацааны дараа хэрэгжүүлэх замгүй болмогцоо ямар ч ачаа үүрэхээ больдог. Чи Бурханы үгийг зүгээр л идэж, ууснаараа ачаа бий болгож чадахгүй. Олон үнэнийг ойлгосноор чи ялган таних чадвартай болж, үнэнийг ашиглан асуудлуудыг шийдвэрлэж сураад, Бурханы үг, Бурханы хүслийн талаар илүү нарийн ойлголттой болно. Эдгээр зүйлтэй байснаар чи үүрэх ачаа бий болгох бөгөөд тэр үед л ажлыг зүй зохистойгоор гүйцэтгэж чадна. Чи ачаатай боловч үнэний талаар тодорхой ойлголтгүй бол бас л нэмэргүй; чи Бурханы үгийг биечлэн туулж, тэдгээрийг хэрхэн

хэрэгжүүлэхээ мэддэг байх ёстой. Чи өөрөө бодит байдалд орсны дараа л бусдыг хангаж, удирдан хөтөлж, Бурханаар төгс болгуулж чадна.

“Зам… 4”-т, та нар бол эрин үеүдээс өмнө Бурханы урьдчилан тогтоосон хаанчлалын ардууд бөгөөд үүнийг хэн ч булаан авч чадахгүй хэмээн бичсэн байдаг. Түүнчлэн, хүн бүр Бурханаар ашиглуулж, төгс болгуулаасай гэж Бурхан хүсдэг бөгөөд Бурханы ардууд болон зогсохыг хүмүүсээс шаарддаг, Бурханы ардууд болсноор л тэд Бурханы хүслийг биелүүлж болох юм гэж тэнд өгүүлдэг. Тэр үед та нар бүгд энэ асуудлын талаар нөхөрлөж, Бурханы ардуудад тавигдах стандартад үндэслэн оролтын замын тухай ярилцсан. Тиймээс тэр үед Ариун Сүнсний хийсэн ажил нь бүх хүнийг сөрөг байдлаас нь гаргаж, эерэг байдал руу хөтлөх явдал байсан юм. Тухайн үед Ариун Сүнсний ажил нь, Бурханы ардуудын хувиар Бурханы үгийг эдлэх боломжийг хүн бүрд олгож, та нар бол эрин үеүдээс өмнө урьдчилан тогтоогдсон Бурханы ардууд бөгөөд Сатан та нарыг авч чадахгүй гэдгийг та бүхэнд тодорхой ойлгуулахаар зорьж байсан юм. Иймээс та нар бүгдээрээ “Бурхан минь! Эрин үеүдээс өмнө Та биднийг урьдчилан тогтоож, энэ байр суурийг бидэнд олгосон учир би Таны ардуудын нэг байхыг хүсэж байна. Бид энэ байрнаас Таныг сэтгэл хангалуун байлгахыг хүсэж байна” хэмээн залбирсан. Ийм маягаар залбирах бүрд чинь Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөдөг байсан; Ариун Сүнс ингэж ажиллахаар зорьж байсан юм. Одоо бол чи залбирч, Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж сурах ёстой, ингэснээр чи амийг эрэлхийлж, хаанчлалын сургалтад орохоор эрж хайж чадна. Энэ бол эхний алхам. Яг одоо Бурханы ажил нь хүн бүрийг зөв замд оруулж, хэвийн сүнслэг амьдрал, үнэн бодит туршлагатай байлгаж, Ариун Сүнсээр сэтгэлийг нь хөдөлгөж, эдгээрийн үндсэн дээр Бурханы даалгаврыг хүлээн авхуулахын төлөө байдаг. Хаанчлалын сургалтад орохын зорилго нь та нарын үг, үйл хэрэг, хөдөлгөөн, бодол, санаа бүрийг Бурханы үгэнд оруулах; Бурхан илүү олон удаа сэтгэлийг чинь хөдөлгөж, улмаар та нарыг Бурханыг хайрлах зүрх сэтгэлтэй болгох; та нарт Бурханы хүслийн ачаанаас илүү ихийг үүрүүлэхийн төлөө байдаг бөгөөд ингэснээр хүн бүр Бурханаар төгс болгуулах замд орж, хүн бүр зөв замд ордог. Бурханаар төгс болгуулах зам дээр байгаа цагт чи зөв зам дээр байна. Бодол, санаа болон буруу сэдлийг чинь засаж залруулах боломжтой болж, чи махан биеэ анхаардаг байснаа Бурханы хүслийг анхаарч чаддаг болж, буруу сэдэл төрөх бүрд анхаарлаа сарниулахгүй тэвчиж, оронд нь Бурханы хүслийн дагуу үйлдэж чаддаг болмогц— ийм өөрчлөлтөд хүрч чадвал чи амийн туршлагын зөв замд байна. Залбирлын дадал чинь зөв замд ормогц залбирлын чинь явцад Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөнө. Залбирах бүрд чинь Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөнө; залбирах бүрдээ чи Бурханы өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж чадна. Бурханы үгийн хэсгийг идэж, уух болгондоо Бурханы одоо гүйцэтгэж буй ажлыг ухаарч, хэрхэн залбирах, хэрхэн хамтран ажиллах, хэрхэн орохыг сурч чаддаг бол тэр үед л Бурханы үгийг идэж, ууж байгаа чинь үр дүнгээ өгнө. Бурханы үгээр дамжуулан

орох замыг олж, Бурханы ажлын одоогийн хөдөлгөөн болон Ариун Сүнсний ажлын чиглэлийг ялган таньж чаддаг бол чи зөв замд орсон байх болно. Бурханы үгийг идэж, ууж байхдаа гол санаанууд ыг нь ойлгоогүй, дараа нь хэрэгжүүлэх замыг олж чадахгүй хэвээр байвал чи Бурханы үгийг хэрхэн зохистой идэж, уухаа мөн л мэддэггүй бөгөөд тэгэх арга, зарчмыг олж мэдээгүй байгааг энэ нь харуулна. Хэрвээ чи Бурханы одоо хийж байгаа ажлыг ойлгоогүй бол Бурханы даалгах үүрэг даалгаврыг хүлээн авч чадахгүй. Бурханы одоо хийж байгаа ажил нь хүмүүсийн одоо орох, ойлгох ёстой ажил юм. Та нар эдгээр зүйлийг ойлгож байна уу?

Хэрвээ чи Бурханы үгийг үр дүнтэйгээр идэж, уугаад, сүнслэг амьдрал чинь хэвийн болдог бөгөөд ямар шалгалттай нүүр тулж, ямар нөхцөл байдалтай тулгарч, бие махбодын ямар өвчин эмгэгийг тэсвэрлэж, ах, эгч нарын ямар гадуурхал, эсвэл гэр бүлийн ямар хүндрэл бэрхшээл туулсан чинь хамаагүй, Бурханы үгийг хэвийн байдлаар идэж, уун, хэвийн байдлаар залбирч, чуулганы амьдралаа хэвийн байдлаар үргэлжлүүлж чаддаг бол; хэрвээ энэ бүхнийг хийж чаддаг бол зөв зам дээр байгааг чинь энэ нь харуулна. Зарим хүн хэтэрхий эмзэг бөгөөд тэсвэр тэвчээргүй байдаг. Тэд багахан саадтай тулгараад гонгинож, сөрөг болдог. Үнэний эрэл хайгуул нь тэсвэр тэвчээр, шийдэмгий байдлыг шаарддаг. Чи энэ удаад Бурханы хүслийг хангалуун байлгаж чадаагүй бол өөрийгөө зэвүүцэж, дараагийн удаа амжилтад хүрнэ гэж дотроо чимээгүйхэн шийдэж чаддаг байх ёстой. Хэрэв энэ удаад Бурханы ачааг анхааралагүй бол хожим нь адилхан саад бэрхшээлтэй нүүр тулахдаа махан биеийг эсэргүүцэж, Бурханы хүслийг хангалуун байлгахаар сэтгэл шулуудсан байх ёстой. Ингэж байж чи магтуулахуйц болно. Зарим хүн бодол, эсвэл санаа нь зөв эсэхийг ч мэддэггүй; тэр хүмүүс бол тэнэгүүд! Чи зүрх сэтгэлээ захирч, махан биеийг эсэргүүцэхийг хүсвэл эхлээд санаа зорилго чинь зөв эсэхийг мэдэх ёстой; тэр үед л чи зүрх сэтгэлээ захирч чадна. Хэрвээ чи санаа зорилго чинь зөв эсэхийг мэдэхгүй бол зүрх сэтгэлээ захирч, махан биеийг эсэргүүцэж чадна гэж үү? Эсэргүүцсэн ч чи будилсан байдлаар эсэргүүцнэ. Андуу ташаа санаа зорилгоо хэрхэн эсэргүүцэхээ чи мэддэг байх хэрэгтэй; махан биеийг эсэргүүцэх гэж үүнийг хэлдэг юм. Санаа зорилго, бодол, санаа чинь буруу гэдгийг мэдсэн даруйдаа чи чиглэлээ өөрчилж, зөв замаар алхах хэрэгтэй. Энэ асуудлыг эхлээд шийд, мөн үүнтэй холбогдуулан орохын тулд өөрийгөө сурга, учир нь зөв санаа зорилготой эсэхээ чи хамгийн сайн мэдэж байгаа. Андуу ташаа санаа зорилго чинь засагдаж, Бурханы төлөө байдаг болмогц чи зүрх сэтгэлээ захирах зорилгодоо хүрсэн байх болно.

Та нарын одоо хийх хамгийн чухал зүйл бол Бурхан болон Түүний ажлын талаар мэдлэг олж авах явдал юм. Чи бас Ариун Сүнс хүмүүс дээр ажлаа хэрхэн гүйцэтгэдгийг мэдэх ёстой; эдгээр үйлдэл нь зөв замд ороход нэн чухал юм. Чи гол санааг ойлгосон цагт үүнийг хийхэд илүү амархан байх болно. Чи Бурханд итгэдэг, Бурханыг мэддэг бөгөөд энэ нь Бурханд итгэх итгэл чинь жинхэнэ гэдгийг харуулдаг. Чи үргэлжлүүлэн туршлага хуримтлуулдаг атлаа эцэст нь Бурханыг

мэдэж чадахгүй хэвээр байвал Бурханыг эсэргүүцдэг хүн гэдэг чинь гарцаагүй. Өнөөгийн бие махбодтой болсон Бурханд ч бас итгэлгүйгээр зөвхөн Есүс Христэд итгэдэг хүмүүс бүгд яллагддаг. Тэд бол бүгд хожмын үеийн фарисайчууд юм, учир нь тэд өнөөгийн Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй, бүгд Бурханы эсрэг байдаг. Тэд Есүсийг шүтэхдээ өөрсдийгөө хэрхэн зориулсан нь хамаагүй, бүгд талаар өнгөрнө; Бурхан тэднийг магтахгүй. Бурханд итгэдэг гэх нэртэй атлаа зүрх сэтгэлдээ Бурханы талаар ямар ч жинхэнэ мэдлэггүй байдаг бүх хүн нь хоёр нүүртнүүд юм!

Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлэхийн тулд хүн Бурханаар төгс болгуулах гэж юу гэсэн үг болохыг, төгс болгуулахын тулд ямар нөхцөлийг биелүүлсэн байх ёстойгоо эхлээд ойлгох ёстой. Эдгээрийг ойлгомогцоо хүн хэрэгжүүлэлтийн замыг хайх ёстой. Төгс болгуулахын тулд тодорхой хэв чанартай байх ёстой. Олон хүн төрөлхөөсөө хангалттай хэв чанартай байдаггүй бөгөөд тэр тохиолдолд чи төлөөс төлж, хувийн үзэл бодлын үүднээс шаргуу хөдөлмөрлөх ёстой. Хэв чанар чинь муу байх тусам илүү хувийн хүчин чармайлт гаргах ёстой. Чи Бурханы үгийг ойлгож, Бурханы үгийг хэрэгжүүлэх тусмаа төгс төгөлдрийн замд илүү хурдан хөл тавих болно. Залбирлаар дамжуулан чи залбирлын талбарт төгс болгуулж чадна; бас Бурханы үгийг идэж, ууж, тэдгээрийн мөн чанарыг ойлгож, Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулснаар төгс болгуулж чадна. Бурханы үгийг өдөр тутам туулснаар өөрт чинь юу дутагдаж байгааг мэдэж авах ёстой; түүнчлэн, хөнөөлт дутагдал болон сул талаа танин мэдэж, Бурханд залбирч, Бурханаас гуйх хэрэгтэй. Тэгснээр чи аажмаар төгс болгуулна. Төгс төгөлдөрт хүрэх зам бол: залбирах, Бурханы үгийг идэж, уух, Бурханы үгийн мөн чанарыг ухаарах; Бурханы үгийн туршлагад орох; өөртөө дутагдаж буй зүйлийг мэдэж авах; Бурханы ажилд захирагдах; Бурханыг гэх хайраараа дамжуулан Бурханы ачааг анхаарч, махан биеийг хаях; ах, эгч нартайгаа байнгын нөхөрлөх явдал, энэ нь туршлагыг чинь баяжуулж чадна. Нийтийн амьдрал ч бай, хувийн амьдрал ч бай хамаагүй, том эсвэл жижиг цугларалт ч бай хамаагүй, энэ бүхэн нь чамд туршлага хуримтлуулж, сургалт хүлээж авах боломж олгож, ингэснээр Бурханы өмнө зүрх сэтгэл чинь тайван байж, Бурхан руу эргэн ирж чадна. Энэ бүхэн нь төгс болгуулах үйл явцын нэг хэсэг юм. Өмнө дурдсанчлан, Бурханы үгийг туулах гэдэг нь үнэхээр Бурханы үгийг амталж, амьдран харуулж чаддаг байна гэсэн үг бөгөөд ингэснээр чи Бурханд итгэх илүү их итгэл, хайрыг олж авна. Ийм маягаар чи завхарсан, сатанлаг зан чанараа аажмаар хаяж; зохисгүй сэдлээс өөрийгөө чөлөөлж; хэвийн хүний төрхийг амьдран харуулна. Чиний дотор Бурханыг гэх хайр хэдий чинээ их байна, өөрөөр хэлбэл, чи Бурханаар хэдий чинээ төгс болгуулна, Сатаны завхралд төдий чинээ бага автана. Чи бодит туршлагаараа дамжуулан, төгс болгуулах замд аажмаар хөл тавина. Тиймээс, хэрвээ чи төгс болгуулахыг хүсдэг бол Бурханы хүслийг анхаарч, Бурханы үгийг туулах нь нэн чухал юм.

ӨӨРИЙНХ НЬ ЗҮРХ СЭТГЭЛИЙН ДАГУУХ ХҮМҮҮСИЙГ БУРХАН ТӨГС БОЛГОДОГ

Өөртэй нь хамтран ажиллахыг хичээдэг, Түүний ажлыг дуулгавартай дагаж чаддаг, Бурханы хэлдэг үгийг үнэн гэж итгэдэг, Бурханы шаардлагыг хэрэгжүүлж чаддаг хүмүүсээс бүрддэг тодорхой бүлэг хүмүүсийг Бурхан одоо олж авахыг хүсдэг; тэд бол зүрх сэтгэлдээ жинхэнэ ойлголттой, төгс болгуулж чадах хүмүүс бөгөөд төгс болгуулах замаар гарцаагүй алхаж чадна. Төгс болгуулж чадахгүй хүмүүс нь Бурханы ажлын талаар тодорхой ойлголтгүй, Бурханы үгийг идэж уудаггүй, Түүний үгийг анхаардаггүй, зүрх сэтгэлдээ Бурханыг гэх хайргүй хүмүүс юм. Бие махбодтой болсон Бурханд эргэлзэж, Түүний талаар үргэлж тээнэгэлзэн, үгийг нь хэзээ ч нухацтайгаар авч үзэлгүй, Түүнийг үргэлж мэхэлдэг хүмүүс бол Бурханыг эсэргүүцдэг, Сатанд харьяалагддаг хүмүүс юм; ийм хүмүүсийг төгс болгох ямар ч аргагүй.

Хэрвээ чи төгс болгуулахыг хүсвэл эхлээд Бурханд таалагдах ёстой, учир нь Тэр Өөрт нь таалагддаг, Өөрийнх нь зүрх сэтгэлийн дагуух хүмүүсийг төгс болгодог билээ. Хэрэв чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхыг хүсвэл Түүний ажлыг дуулгавартай дагадаг зүрх сэтгэлтэй байж, үнэнийг эрэлхийлэхээр хичээж, бүх зүйл дээр Бурханы шинжилтийг хүлээн зөвшөөрөх ёстой. Чиний хийдэг бүхэн Бурханы шинжилтийг давсан уу? Санаа зорилго чинь зөв үү? Хэрэв санаа зорилго чинь зөв бол Бурхан чамайг сайшаана; хэрэв санаа зорилго чинь буруу бол зүрх сэтгэлийн чинь хайрладаг зүйл Бурхан биш, харин махан бие, Сатан юм гэдгийг харуулдаг. Тиймээс чи бүх зүйл дээр Бурханы шинжилтийг хүлээн зөвшөөрөх арга зам болгож залбирлыг ашиглах ёстой. Залбирах үед чинь Би хэдийгээр өмнө чинь биечлэн зогсож байхгүй ч Ариун Сүнс чамтай хамт байдаг бөгөөд Надад болон Бурханы Сүнсэнд хоёуланд нь чи залбирч байгаа. Чи энэ махбодод яагаад итгэдэг вэ? Түүнд Бурханы Сүнс байдаг учраас чи итгэдэг. Энэ хүнд Бурханы Сүнс байхгүй байсан бол чи Түүнд итгэх байсан уу? Чи энэ хүнд итгэхдээ Бурханы Сүнсэнд итгэдэг. Чи энэ хүнээс эмээхдээ Бурханы Сүнснээс эмээдэг. Бурханы Сүнсэнд итгэх итгэл нь энэ хүнд итгэх итгэл бөгөөд энэ хүнд итгэх итгэл нь мөн Бурханы Сүнсэнд итгэх итгэл юм. Чи залбирах үедээ Бурханы Сүнс чамтай хамт байгааг, Бурхан чиний өмнө байгааг мэдэрдэг, тиймээс ч чи Түүний Сүнсэнд залбирдаг. Өнөөдөр ихэнх хүмүүс үйлдлээ Бурханы өмнө авчрахаас хэтэрхий их айдаг; чи Түүний махбодыг мэхэлж магадгүй ч Түүний Сүнсийг мэхэлж чадахгүй. Бурханы шинжилтийг тэсвэрлэж чадахгүй аливаа хэрэг явдал үнэнтэй таардаггүй бөгөөд үүнийг хаях хэрэгтэй; үүнээс өөрөөр хийх нь Бурханы эсрэг нүгэл үйлдэж байгаа хэрэг. Иймээс чи залбирах үедээ, ах эгч нартайгаа ярилцаж, нөхөрлөх үедээ, үүргээ гүйцэтгэж, ажил хэргээ явуулах үедээ зүрх сэтгэлээ цаг үргэлж Бурханы өмнө тавих ёстой. Үүргээ биелүүлэх үед чинь Бурхан чамтай хамт байдаг бөгөөд санаа зорилго чинь зөв, Бурханы гэрийн ажлын төлөө байгаа цагт хийдэг бүхнийг

чинь Тэр хүлээн зөвшөөрнө; чи үүргээ биелүүлэхэд чин сэтгэлээсээ өөрийгөө зориулах хэрэгтэй. Залбирах үедээ зүрх сэтгэлд чинь Бурханыг гэсэн хайр байдаг, Бурханы халамж, хамгаалалт, шинжилтийг эрэлхийлдэг бол, хэрэв эдгээр зүйл санаа зорилго чинь бол чиний залбирал үр дүнтэй байна. Жишээлбэл, цуглаан дээр залбирах үедээ чи зүрх сэтгэлээ нээж, Бурханд залбиран, худал хуурмаг зүйл ярилгүйгээр зүрх сэтгэлдээ байгаа зүйлийг Түүнд хэлбэл залбирал чинь гарцаагүй үр дүнтэй болно. Хэрэв чи зүрх сэтгэлдээ Бурханыг үнэхээр хайрладаг бол “Тэнгэр, газарт болон бүх зүйлийн дунд байдаг Бурхан Танд би амлая: Таны Сүнс миний хийдэг бүхнийг шалгаж, намайг цаг үргэлж хамгаалж, халамжлан, хийдэг бүх зүйлээ Таны өмнө байлгах боломж олгох болтугай. Миний зүрх сэтгэл Таныг хайрлахаа боливол, эсвэл хэзээ нэгэн цагт Танаас урвавал намайг хатуу чангаар гэсгээж, хараа. Энэ амьдралд ч, дараагийн амьдралд ч намайг бүү өршөө!” хэмээн Бурханд тангарагла. Чи ийм тангараг өгч зүрхлэх үү? Хэрэв чи ингэж зүрхлэхгүй бол хулчгар бөгөөд өөрийгөө хайрласаар байгааг чинь энэ нь харуулдаг. Чамд ингэх шийдвэр байна уу? Хэрэв үнэхээр ингэж шийдсэн бол ийм тангараг өгөх хэрэгтэй. Хэрэв чамд ингэж тангараглах шийдвэр байгаа бол Бурхан шийдвэрийг чинь биелүүлнэ. Чамайг Бурханд тангараг өгөхөд Тэр сонсдог. Чиний залбирал, хэрэгжүүлэлтийг хэмжсэнээр Бурхан нүгэлтэй юу, эсвэл зөв шударга уу гэдгийг чинь тодорхойлдог. Энэ нь одоо та нарыг төгс болгох үйл явц бөгөөд хэрэв чамд төгс болгуулах итгэл үнэхээр байвал хийдэг бүхнээ Бурханы өмнө авчирч, Түүний шинжилтийг хүлээж авах болно; хэрэв чи хэтэрхий тэрслүү зүйл хийх юм уу Бурханаас урвавал Тэр тангаргийг чинь биелүүлнэ, ингэснээр мөхөл ч бай, гэсгээлт ч бай, чамд юу ч тохиолдсон хамаагүй, энэ нь өөрийн чинь хийсэн хэрэг юм. Чи тангараг өгсөн тул үүнийгээ мөрдөх ёстой. Хэрэв чи тангараг өгдөг боловч мөрддөггүй бол мөхөх болно. Чинийх тангараг байсан болохоор Бурхан тангаргийг чинь биелүүлнэ. Зарим хүн залбирсныхаа дараа айж, “Бүх зүйл өнгөрлөө! Миний самуун амьдрах боломж үгүй боллоо; хорон муу зүйл хийх боломж үгүй боллоо; орчлон хорвоогийн хүсэлд ташуурах боломж үгүй боллоо!” хэмээн халагладаг. Энэ хүмүүс хорвоогийн юмс болон нүглийг хайрласаар байдаг бөгөөд мөхөх нь гарцаагүй.

Бурханд итгэгч байна гэдэг нь хийж буй бүхнээ Түүний өмнө авчирч, шинжүүлэх ёстой гэсэн үг юм. Хийж буй зүйлээ Бурханы Сүнсний өмнө авчирч болох боловч Бурханы махбодын өмнө авчирч болохгүй бол чи Түүний Сүнсээр шинжүүлж байгаагүйг харуулж байна. Бурханы Сүнс гэж хэн бэ? Бурхан гэрчлэл хийдэг хүн хэн бэ? Тэд нэг биш гэж үү? Ихэнх нь Тэднийг хоёр тусдаа оршихуй гэж үзэн, Бурханы Сүнс бол Бурханы л Сүнс, харин Бурхан гэрчлэл хийдэг хүн бол ердөө л нэг хүн гэж итгэдэг. Гэвч чи андуурсан бус уу? Энэ хүн хэний өмнөөс ажилладаг вэ? Бие махбодтой болсон Бурханыг мэддэггүй хүмүүст сүнслэг ойлголт байдаггүй. Бурханы Сүнс, Түүний махбод болсон бие хоёр нэг бөгөөд учир нь Бурханы Сүнс махбодод биеллээ олдог. Энэ хүн чамд базаахгүй хандвал Бурханы Сүнс эелдэг хандана гэж үү? Чи будилсан бус уу? Өнөөдөр Бурханы шинжихийг хүлээн авч

чаддаггүй бүхэн Түүний сайшаалыг хүртэж чадахгүй бөгөөд бие махбодтой болсон Бурханыг мэддэггүй хүмүүс төгс болгуулж чадахгүй. Хийж байгаа бүхнээ хараад Бурханы өмнө авчирч болох эсэхийг үзээрэй. Хийж байгаа бүхнээ Бурханы өмнө авчирч чадахгүй бол энэ нь мууг үйлдэгч болохыг чинь харуулж байна. Мууг үйлдэгч төгс болгуулж чадах уу? Үйлдэл, санаа зорилго, хариу үйлдэл бүр гээд хийж буй бүхнээ Бурханы өмнө авчрах хэрэгтэй. Чиний залбирал, Бурхантай ойр дотно байдал, Бурханы үгийг хэрхэн идэж уудаг, ах эгч нартайгаа хийсэн нөхөрлөл, чуулган доторх амьдрал, түншлэл дэх үйлчлэл гээд өдөр тутмын сүнслэг амьдралаа хүртэл Бурханы өмнө авчирч шинжүүлэх хэрэгтэй. Ийм хэрэгжүүлэлт амиа өсгөхөд чинь тусална. Бурханы шинжилтийг хүлээн авах явц нь ариусах явц юм. Бурханы шинжихийг хүлээн авч чадах тусам улам их ариусаж, Бурханы хүсэлд улам их нийцсэнээрээ самуун явдалд татагдахгүй, зүрх сэтгэл чинь Түүний өмнө амьдарна. Түүний шинжлэхийг хүлээн зөвшөөрөх тусам Сатан улам их шившиглэгдэж, махан биеэ хаях чадвар чинь улам нэмэгдэнэ. Тиймээс Бурханы шинжлэхийг хүлээн авах нь хүмүүсийн дагах ёстой хэрэгжүүлэлтийн зам юм. Чи юу ч хийж байсан бай, ах эгч нартайгаа ярилцахдаа хүртэл үйлдлээ Бурханы өмнө авчирч, Түүнээр шинжүүлэхийг хичээж, Бурханыг Өөрийг нь дуулгавартай дагахаар зорьж болно. Энэ нь хэрэгжүүлдэг зүйлийг чинь хавьгүй илүү зөв болгоно. Чи хийж байгаа бүхнээ Бурханы өмнө авчирч, Бурханы шинжихийг хүлээн зөвшөөрөх л юм бол Бурханы өмнө амьдардаг нэгэн болж чадна.

Бурханы талаар ойлгодоггүй хүмүүс Бурханыг хэзээ ч бүрэн дуулгавартай дагаж чадахгүй. Ийм хүмүүс бол дуулгаваргүй байдлын хөвгүүд юм. Тэд хэтэрхий их санаатай, дотроо хэтэрхий их тэрслүү учраас Бурханаас холдож, Түүний шинжилтийг хүлээн зөвшөөрөх хүсэлгүй байдаг. Ийм хүмүүсийг төгс болгоход амаргүй. Зарим хүн Бурханы үгийг идэж уух болон хүлээн зөвшөөрөхдөө голж шилдэг. Тэд Бурханы үгээс өөрсдийнх нь үзэлд нийцдэг тодорхой хэсгийг хүлээн зөвшөөрөөд, нийцэхгүйг нь үл хэрэгсдэг. Энэ чинь Бурханы эсрэг хамгийн илэрхий тэрслэлт, эсэргүүцэл биш гэж үү? Хүн Бурханы талаар өчүүхэн ч ойлголт олж авалгүйгээр олон жил итгэж байгаа бол үл итгэгч юм. Бурханы шинжихийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа хүмүүс бол Түүнийг ойлгохоор эрэлхийлдэг, Түүний үгийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэг хүмүүс юм. Тэд Бурханы өв болон ерөөлийг хүлээн авах хүмүүс бөгөөд хамгийн их ерөөгдсөн хүмүүс юм. Зүрх сэтгэлд нь Түүнд зориулсан орон зай үгүй хүмүүсийг Бурхан хараж, ийм хүмүүсийг гэсгээж, хаядаг. Чи Бурханыг хайрладаггүй бол Тэр чамайг хаяна, Миний хэлэхийг сонсдоггүй бол Бурханы Сүнс чамайг хаяна гэдгийг Би амлая. Итгэхгүй бол оролдоод үз! Өнөөдөр Би чамд хэрэгжүүлэлтийн замыг тодруулж өгье, гэвч хэрэгжүүлэх эсэхээ өөрөө шийд. Хэрэв чи үүнд итгэдэггүй бол, үүнийг хэрэгжүүлдэггүй бол Ариун Сүнс дотор чинь ажилладаг эсэхийг өөрөө харах болно! Чи Бурханыг ойлгохоор эрэлхийлдэггүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй. Үгийг нь эрэлхийлж, эрхэмлэдэг хүмүүсийн дотор Бурхан ажилладаг. Бурханы үгийг эрхэмлэх тусам

Ариун Сүнс чиний дотор илүү их ажиллана. Хүн Бурханы үгийг эрхэмлэх тусам Бурханаар төгс болгуулах боломж нь төдий чинээ нэмэгдэнэ. Өөрийг нь үнэхээр хайрладаг хүмүүсийг Бурхан төгс болгодог бөгөөд Өөрийнх нь өмнө зүрх сэтгэлээ тайван байлгадаг хүмүүсийг Тэр төгс болгодог. Бурханы бүх ажлыг эрхэмлэх, Бурханы гэгээрлийг эрхэмлэх, Бурханы хамт байгааг эрхэмлэх, Бурханы халамж, хамгаалалтыг эрхэмлэх, Бурханы үг хэрхэн бодит байдал чинь болж, амийг чинь хангаж байгааг эрхэмлэх нь бүгд Бурханы зүрх сэтгэлтэй хамгийн сайн нийцдэг. Хэрвээ чи Бурханы ажлыг эрхэмлэдэг бол, өөрөөр хэлбэл, чам дээр хийсэн Түүний бүх ажлыг эрхэмлэдэг бол Тэр чамайг ерөөж, чиний бүх зүйлийг өсгөж үржүүлэх болно. Чи Бурханы үгийг эрхэмлэдэггүй бол Тэр чиний дотор ажиллахгүй, харин итгэлийн чинь төлөө өчүүхэн нигүүлсэл соёрхоно, эсвэл чамайг багахан эд баялаг, гэр бүлийг чинь багахан амар амгалан байдлаар ерөөнө. Чи Бурханы үгийг бодит байдлаа болгон, Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, Түүний зүрх сэтгэлийн дагуу байж чаддаг байхаар хичээх ёстой. Ердөө л Түүний нигүүлслийг эдлэхийн төлөө мэрийх ёсгүй. Итгэгчдийн хувьд Бурханы ажлыг хүлээн авч, төгс болгуулж, Бурханы хүслийг биелүүлдэг хүмүүс болохоос илүү чухал зүйл үгүй. Энэ бол чиний эрэлхийлэх ёстой зорилго юм.

Нигүүлслийн эрин үед хүний эрэлхийлж байсан бүхэн одоо үеэ өнгөрөөсөн, учир нь одоо эрэл хайгуулын илүү өндөр стандарт гэж бий, эрэлхийлдэг зүйл илүү сүрлэг, илүү бодитой бөгөөд эрэлхийлж буй зүйл хүний дотоод хэрэгцээ шаардлагыг илүү сайн хангаж чадна. Бурхан өнгөрсөн эрин үеүдэд, өнөөдрийнх шигээ хүмүүс дээр ажиллаагүй; өнөөдрийнх шигээ хүмүүстэй ярилцаагүй; хүмүүст тавьдаг Түүний шаардлагууд ч өнөөдрийнх шиг өндөр байгаагүй. Бурхан одоо эдгээр зүйлийг та нарт хэлж байгаа нь Бурханы эцсийн санаа зорилго энэ хэсэг хүмүүс, та нар дээр төвлөрдгийг харуулж байна. Хэрэв чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хүсэж байгаа бол үүнийг гол зорилгоо болгон эрэлхийл. Ийш тийшээ гүйж байна уу, өөрийгөө зарлагадаж байна уу, чиг үүрэг биелүүлж байна уу, эсвэл Бурханы даалгаврыг хүлээж авсан уу гэдэг нь хамаагүй, зорилго нь үргэлж төгс болгуулж, Бурханы хүслийг биелүүлж, эдгээр зорилгод хүрэхийн төлөө байдаг. Хэрвээ хүн Бурханаар төгс болгуулахаар, эсвэл амь руу орохоор эрэлхийлдэггүй, харин бие махбодын амар амгалан, баяр хөөрийг л эрэлхийлдэг бол хамгийн сохор хүн юм. Амь-бодит байдлыг эрэлхийлдэггүй, харин зөвхөн ирэх ертөнц дэх үүрдийн амьдрал, энэ ертөнц дэх аюулгүй байдлыг л эрэлхийлдэг бол тэд хамгийн сохор хүмүүс юм. Тиймээс хийж буй бүхнээ Бурханаар төгс болгуулж, авхуулах зорилгоор хийх хэрэгтэй.

Хүмүүст Бурханы хийдэг ажил бол өөр өөр шаардлагад нь үндэслэн тэднийг хангах явдал юм. Хүний амь том байх тусмаа ихийг шаардаж, ихийг эрэлхийлдэг. Энэ үе шатанд чамд ямар ч эрэл хайгуул байдаггүй бол Ариун Сүнс чамайг орхисон гэдгийг энэ нь баталж байна. Амийг эрэлхийлдэг бүх хүнийг Ариун Сүнс хэзээ ч хаяхгүй, ийм хүмүүс үргэлж эрэлхийлж, зүрх сэтгэлдээ үргэлж хүсэл тэмүүлэлтэй

байдаг. Ийм хүмүүс байгаа байдалдаа хэзээ ч сэтгэл ханадаггүй. Ариун Сүнсний ажлын үе шат бүр чамд үр нөлөө үзүүлэхийг зорьдог боловч хэрэв чи өөртөө сэтгэл ханавал, чамд хэрэгцээ байхаа боливол, Ариун Сүнсний ажлыг хүлээн зөвшөөрөхөө боливол Тэр чамайг хаях болно. Хүмүүс өдөр бүр Бурханаар шинжүүлэх шаардлагатай; тэдэнд Бурханы элбэг дэлбэг хангалт өдөр бүр хэрэгтэй. Хүмүүс Бурханы үгийг өдөр бүр идэж уулгүйгээр байж чадах болов уу? Хэрэв хэн нэгэнд Бурханы үгийг хангалттай идэж ууж чадахгүй байгаа мэт санагдаж, үргэлж эрж хайж, Түүний үгээр өлсөж цангаж байвал Ариун Сүнс үргэлж дотор нь ажиллана. Хүн хүсэж эрмэлзэх тусам нөхөрлөлөөс нь илүү бодитой зүйлс гарч болно. Хүн үнэнийг эрчимтэйгээр эрж хайх тусам амийн өсөлтөд улам хурдан хүрч, Бурханы гэрийн арвин туршлагатай, чинээлэг оршин суугч болно.

БУРХАНД ҮНЭНЧ ЗҮРХ СЭТГЭЛЭЭР ДУУЛГАВАРТАЙ БАЙДАГ ХҮМҮҮСИЙГ БУРХАН ГАРЦААГҮЙ ОЛЖ АВНА

Ариун Сүнсний ажил өдрөөс өдөрт өөрчлөгдөж, алхам тутамдаа улам өндөрт дээшилж, маргаашийн илчлэл алхам алхмаар бүр ч өндөрт өгсөн, өнөөдрийнхөөс ч илүү өндөр болдог. Бурхан хүнийг төгс болгодог ажил нь ийм юм. Хүмүүс хөл нийлүүлэн алхаж чадахгүй бол хэдийд ч таягдан хаягдаж магадгүй. Хүмүүст дуулгавартай байх зүрх сэтгэл үгүй бол эцэст нь хүртэл дагаж чадахгүй. Урьдын эрин үе өнгөрчихсөн; энэ бол шинэ эрин үе. Шинэ эрин үед шинэ ажил хийгдэх ёстой. Ялангуяа хүмүүсийг төгс болгох сүүлчийн эрин үед Бурхан илүү шинэ ажлыг бүр ч хурдан гүйцэтгэнэ. Тийм учраас зүрх сэтгэлд нь дуулгавартай байдал байхгүй бол хүмүүст Бурханы мөрийг дагахад хэцүү байдаг. Бурхан ямар ч дүрэмд баригддаггүй, мөн Өөрийн ажлын аль ч шатыг хувиршгүй гэж үздэггүй. Харин ч Түүний хийдэг ажил хэзээд илүү шинэ, улам өндөр байдаг. Түүний ажил алхам бүрд улам бодитой болж, хүний бодит хэрэгцээнд улам бүр нийцдэг. Хүмүүс ийм ажлыг туулсныхаа дараа л зан чанарынхаа сүүлчийн өөрчлөлтөд хүрч чадна. Амийн тухай хүний мэдлэг улам өндөр түвшинд хүрдэг, иймээс Бурханы ажил ч мөн адил улам өндөр түвшинд хүрдэг. Хүн ийм маягаар л төгс болгуулж, Бурхан ашиглахад тохиромжтой болж чаддаг. Бурхан нэг талаар, хүний үзлийг няцааж, өөрчилж, нөгөө талаар, хүнийг илүү өндөр, илүү бодитой байдал руу, Бурханд итгэх итгэлийн хамгийн өндөр түвшин рүү хөтлөхийн тулд ийм маягаар ажилладаг, тэгснээр Бурханы хүсэл эцэст нь биелж чадна. Дур зоргоороо тэрсэлдэг дуулгаваргүй уг чанартай хүмүүс, Бурханы хурдтай бөгөөд эрчтэй урагшлах ажлын энэ үе шатанд бүгдээрээ таягдан хаягдах болно; сайн дурааараа дуулгавартай байдаг, дуртайяа өөрсдийгөө даруу болгодог хүмүүс л замын төгсгөл хүртэл урагшилж чадна. Энэ төрлийн ажилд хэрхэн захирагдахыг, мөн өөрийн үзлийг хэрхэн хаяхыг та нар

бүгдээрээ сурах хэрэгтэй. Алхам бүрдээ хянуур байх хэрэгтэй. Хайнга байвал чи Ариун Сүнсэнд гологдож, Бурханы ажлыг үймүүлдэг нэгэн болох нь дамжиггүй. Ажлын энэ үе шатыг туулахаас өмнө хүний хуучны хууль, дүрэм тоогоо алдаж, хүн учраа олохоо больсон ба үүний уршгаар биеэ тоож, өөрийгөө мартсан. Эдгээр нь цөм Бурханы шинэ ажлыг хүлээж авахаас хүнийг хазаарлаж байдаг саад тотгор юм; тэдгээр нь Бурханы талаарх хүний мэдлэгт дайсагнаж байдаг. Хүмүүс зүрх сэтгэлдээ дуулгавартай биш, бас үнэнийг эгээрэн хүсдэг ч үгүй байх нь аюултай байдаг. Хэрвээ чи зөвхөн энгийн ажил болон үгэнд л захирагддаг, илүү гүн гүнзгий зүйлийг хүлээн авах чадваргүй бол чи хуучнаа баримталдаг, Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлж чадахгүй нэгэн юм. Бурханы хийдэг ажил эрин бүрд ялгаатай байдаг. Чи нэг үе шатанд асар их дуулгавартай байснаа дараагийн үед муу юм уу дуулгавартай байж чадахгүй байвал Бурхан чамайг орхих болно. Бурханыг энэ алхмаар явахад нь чи хөл нийлүүлэн явбал Түүнийг дараачийн алхмаар өгсөхөд үргэлжлүүлэн хөл нийлүүлэн явах ёстой. Гагцхүү тэгсэн цагт л чи Ариун Сүнсэнд дуулгавартай нэгэн байна. Нэгэнт чи Бурханд итгэдэг тул дуулгавартай байдалдаа тууштай хэвээр байх ёстой. Чи зүгээр л дураа хүрэхээр дуулгавартай байж, дургүйгээ хүрэхээр дуулгаваргүй байж болохгүй. Иймэрхүү маягийн дуулгавартай байдлыг Бурхан сайшаадаггүй. Миний нөхөрлөдөг шинэ ажилтай чи алхаа нийлүүлж чадахгүй, урьдын үгтэй зууралдсаар байвал аминд чинь яаж ахиц гарч чадах юм бэ? Бурханы ажил бол үгээрээ дамжуулан чамайг хангах явдал юм. Чи Түүний үгийг дуулгавартай дагаж, хүлээн авсан цагт Ариун Сүнс чам дээр гарцаагүй ажиллана. Ариун Сүнс яг л Миний ярьсны дагуу ажилладаг. Миний хэлснээр хий, тэгээд Ариун Сүнс даруй чам дээр ажиллана. Би та нарыг хараг гэж шинэ гэрэл гаргаж, та нарыг эдүгээ цагийн гэрэл рүү авчирдаг. Чамайг энэ гэрэл рүү алхах үед Ариун Сүнс чам дээр нэн даруй ажиллах болно. “Би зүгээр л Таны хэлсэн зүйлийг хийхгүй” гэж зарим хүн гөжүүдлэн хэлж магадгүй. Тэгэхэд нь Би чамд, одоо чи замын төгсгөлд ирж, хатаж хорчийгоод амьгүй болжээ гэж хэлнэ. Тиймээс зан чанарынхаа өөрчлөлтийг туулах үедээ өнөөгийн гэрэлтэй хөл нийлүүлэн алхах нь хамгийн чухал юм. Ариун Сүнс Бурханы ашигладаг зарим хүн дээр ажиллаад зогсохгүй, мөн чуулганд ажилладаг. Тэр хэн дээр ч ажиллаж байж болно. Одоогоор Тэр чам дээр ажиллаж байж магадгүй бөгөөд чи энэ ажлыг туулна. Дараагийн цаг хугацаанд Тэр өөр хүн дээр ажиллаж болох бөгөөд тэр тохиолдолд чи яаравчлан дагах ёстой; өнөөгийн гэрлийг ойр дагах тусам амь чинь улам их өсөж чадна. Тухайн хүн ямар байх нь хамаагүй, Ариун Сүнс түүн дээр ажиллаж байгаа л бол чи дагах ёстой. Өөрийнхөө туршлагаар дамжуулан түүний туршлагыг мэдэр, тэгээд чи бүр ч өндөр зүйлсийг хүлээж авна. Ингэснээр чи илүү хурдан ахиц гаргана. Энэ бол хүний төгс болгуулах зам, амиа өсгөдөг арга зам юм. Чи Ариун Сүнсний ажилд дуулгавартай байснаар төгс болгуулах замд хүрдэг. Чамайг төгс болгохын тулд Бурхан ямар төрлийн хүнээр дамжуулж ажиллахыг чи мэдэхгүй, мөн ямар хүн, үйл явдал, эсвэл зүйлээр дамжуулан Тэр чамд юмсыг олж

авч эсвэл харах боломж олгохыг ч мэдэхгүй. Хэрвээ чи энэ зөв замд алхан орж чадвал чамд Бурханаар төгс болгуулах асар их найдлага байгааг энэ нь харуулдаг. Хэрвээ чи тэгж чадахгүй бол ирээдүй чинь баргар, гэрэлгүй гэдгийг энэ нь харуулдаг. Зөв замд ормогцоо чи бүх зүйл дээр илчлэл олж авна. Ариун Сүнс бусдад юу илчилдэг байх нь хамаагүй, хэрвээ чи тэдний мэдлэгт үндэслэн аливааг өөрөө туулж мэдэрвэл энэ туршлага амийн чинь нэг хэсэг болох ба энэ туршлагаасаа бусдыг хангаж чадна. Үгийг тоть шиг давтаж бусдыг хангадаг хүмүүс бол ямар ч туршлагагүй хүмүүс юм; чи өөрийн бодит туршлага, мэдлэгийн тухай ярьж эхлэхээсээ өмнө бусдын гэгээрэл, гэрэлтүүлэлтээр дамжуулан хэрэгжүүлэлтийн замыг олж сурах ёстой. Энэ нь чиний өөрийн аминд илүү их ашиг тустай байх болно. Чи Бурханаас ирдэг бүхнийг дуулгавартай дагаж ийм маягаар туршлагажих хэрэгтэй. Чи бүх зүйл дээр Бурханы хүслийг эрж хайж, бүх зүйлээс хичээл сурах хэрэгтэй, тэгвэл чиний амь өснө. Ийм хэрэгжүүлэлт нь хамгийн хурдан ахиц гаргадаг.

Ариун Сүнс бодит туршлагаар чинь дамжуулан чамайг гэгээрүүлж, итгэлээр чинь дамжуулан төгс болгодог. Чи төгс болгуулахыг үнэхээр хүсэж байна уу? Хэрвээ чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хүсэж байгаа бол махан биеэ хаях зоригтой, Бурханы үгийг хэрэгжүүлж чаддаг, мөн идэвхгүй эсвэл сул дорой биш байх болно. Чи Бурханаас ирдэг юм бүхэнд дуулгавартай байж чаддаг, ил, далд хийдэг бүх үйлдэл чинь Бурханд харуулахуйц байх болно. Хэрвээ чи үнэнч шударга бөгөөд бүх зүйл дээр үнэнийг хэрэгжүүлдэг бол төгс болгуулна. Бусдын нүүрэн дээр нэг янзаар, ар хударгаар нь өөр янзаар авирладаг зальжин хүмүүс төгс болгуулах хүсэлгүй байдаг. Тэд бүгдээрээ мөхөл болон сүйрлийн хүүхдүүд билээ; тэд Бурханд биш, харин Сатанд харьяалагддаг. Тэд бол Бурханы сонгодог төрлийн хүн биш! Хэрвээ чиний үйлдэл, зан авир Бурханы өмнө үзүүлж, Бурханы Сүнс шинжилж болохооргүй бол энэ нь чамд асуудал байгаагийн баталгаа юм. Чи Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авч, зан чанарынхаа өөрчлөлтөд санаа тавьсан цагт л төгс болгуулах замд хөл тавьж чадна. Бурханаар төгс болгуулж, Бурханы хүслийг гүйцэтгэхийг үнэхээр хүсэж байгаа бол гомдлын ганц ч үг ган хийхгүй, Бурханы ажлыг үнэлэх буюу шүүж зүрхлэхгүйгээр Бурханы бүх ажлыг дуулгавартай дагах хэрэгтэй. Эдгээр нь Бурханаар төгс болгуулах наад захын шаардлагууд юм. Бурханаар төгс болгуулахаар эрж хайдаг хүмүүсээс шаарддаг хамгийн чухал шаардлага бол бүх зүйлийг Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээр үйлдэх юм. “Бурханыг хайрлах зүрх сэтгэлээр үйлдэх” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь чиний бүх үйлдэл, зан авир Бурханы өмнө үзүүлж болохуйц байна гэсэн үг. Зөв санаа зорилготой учраас үйлдэл чинь зөв ч бай, буруу ч бай, тэрийгээ Бурханд юм уу ах, эгч нартаа харуулахаас айхгүй байж; чи Бурханы өмнө тангараг өргөж зүрхэлдэг. Чи Бурханаар шинжүүлэхийн тулд санаа зорилго, бодол, санаа болгоноо Түүний өмнө үзүүлэх ёстой; ийм маягаар хэрэгжүүлж, орох юм бол чиний амийн ахиц дэвшил хурдан байх болно.

Чи Бурханд итгэдэг учраас Бурханы бүх үг, Түүний бүх ажилд итгэлээ өгөх ёстой. Өөрөөр хэлбэл, чи Бурханд итгэдэг учраас Түүнийг дуулгавартай дагах

ёстой. Хэрвээ ингэж чадахгүй бол Бурханд итгэдэг эсэх чинь хамаагүй. Бурханд олон жил итгэсэн атлаа Түүнийг хэзээ ч дуулгавартай дагаагүй, Түүний бүх үгийг хүлээн аваагүй, харин ч чамд захирагдаж, чиний үзлээр үйлдэхийг Бурханаас шаарддаг бол чи хамгийн тэрслүү бөгөөд үл итгэгч мөн. Хүний үзэлтэй нийцдэггүй Бурханы ажил болон үгийг ийм хүмүүс яаж дуулгавартай дагаж чадах юм бэ? Хамгийн тэрслүү хүн бол Бурханаас санаатайгаар зөрж, эсэргүүцдэг нэгэн юм. Тэд бол Бурханы дайсан, антихрист мөн. Ийм хүмүүс Бурханы шинэ ажилд үргэлж дайсагнасан хандлагатай байдаг, захирагдах өчүүхэн ч дур сонирхол хэзээ ч байгаагүй бөгөөд дуртайяа захирагдаж, өөрийгөө даруу болгосон удаа огт байхгүй. Тэд бусдын өмнө өөрсдийгөө өргөмжилж, хэнд ч хэзээ ч захирагддаггүй. Бурханы өмнө тэд үг номлоход хамгийн шилдэг нь бөгөөд бусад дээр ажиллахдаа хамгийн чадамгай гэж өөрсдийгөө үздэг. Тэд эзэмшсэн “эрдэнэсээ” хэзээ ч хаядаггүй, харин тэдгээрийг шүтэн мөргөх, бусдад номлох гэр бүлийн удам дамжсан эд зүйл мэт үздэг ба өөрсдийг нь шүтдэг тэр мунхгуудад сургаал айлдахдаа тэдгээрийг ашигладаг. Чуулганд үнэндээ иймэрхүү хэдэн хүн байдаг. Тэднийг үеэс үед Бурханы гэрт түр оршин суудаг “мохошгүй баатрууд” гэж хэлж болох юм. Тэд үг (хоосон сургаал) номлохыг өөрсдийн хамгийн эрхэм үүрэг болгодог. Тэд “ариун агаад халдашгүй дархан” үүргээ жилээс жилд, үеэс үед идэвхтэй хэрэгжүүлж явдаг. Тэдэнд хэн ч хүрч зүрхэлдэггүй, ганц ч хүн тэднийг илт зэмлэж зүрхэлдэггүй. Эрин үеэс эрин үед тэд эрээгүй аашлан бусдыг эзэрхэж, Бурханы гэрт “хаан” болдог. Энэ сүрэг чөтгөр гар нийлэн, Миний ажлыг нураах гэж оролддог; энэ амьд диаволууд Миний нүдний өмнө оршин тогтнохыг Би хэрхэн зөвшөөрч чадах билээ? Хагас дутуу дуулгавартай хүмүүс ч эцсийг нь хүртэл үргэлжлүүлж чаддаггүй байхад зүрх сэтгэлдээ өчүүхэн төдий ч дуулгавартай байдалгүй эдгээр эзэрхэг этгээд бүр ч чадахгүй! Бурханы ажлыг хүн олж авахад хялбар биш. Хүмүүс хамаг хүч чадлаа хэрэглээд ч жаахан хэсгийг л олж авч, эцэстээ төгс болгуулж чадна. Тэгэхээр Бурханы ажлыг сүйрүүлэх гэж оролддог тэргүүн тэнгэрэлчийн үр удмын тухайд ямар вэ? Бурханаар авхуулах найдвар тэдэнд бүр ч бага байх бус уу? Байлдан дагуулах ажил хийх Миний зорилго бол гагцхүү байлдан дагуулалтын төлөө байлдан дагуулах бус, харин зөв шударга байдал ба зөв шударга бус байдлыг илчлэх, хүнийг шийтгэх нотолгоо олж авах, хорон мууг яллах, түүнчлэн дуртайяа дуулгавартай дагадаг хүмүүсийг төгс болгохын төлөө байлдан дагуулах явдал билээ. Эцэстээ бүгд төрлийнхөө дагуу ангилагдах бөгөөд төгс болгуулдаг хүмүүсийн бодол, санаа нь ч дуулгавартай байдлаар дүүрдэг. Энэ нь эцэстээ гүйцэлдэх ёстой ажил юм. Харин үйлдэл болгон нь тэрслүү хүмүүс шийтгүүлж, мөнхийн хараалын объект, галд шатаагдахаар хаягдах болно. Тэр цаг ирэхэд өнгөрсөн эрин үеийн “агуу агаад мохошгүй баатрууд” хамгийн адгийн, хамгийн их адлагдсан “үхээнц, сул дорой хулчгарууд” болно. Зөвхөн энэ л Бурханы зөвт байдлын бүх талыг, хүний халдаж чадахгүй Түүний зан чанарыг харуулж чадна. Зөвхөн энэ л Миний зүрх сэтгэл дэх үзэн ядалтыг намдааж чадна. Энэ бүхэн үндэслэлтэй гэдэгтэй та нар санал нийлэхгүй гэж үү?

Ариун Сүнсний ажлыг туулдаг хүн бүр амь олж авч чаддаггүй, энэ урсгалд буй хүмүүс ч бас амь олж авч чаддаггүй. Амь бол бүх хүний хуваалцдаг нийтийн өмч биш бөгөөд зан чанарын өөрчлөлт нь хүн бүхний хялбар хүрдэг зүйл биш билээ. Бурханы ажилд захирагдах нь бодитой байх ёстой бөгөөд амьдран харуулдаг байх ёстой. Дан ганц өнгөн дээрээ захирагдаад Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй бөгөөд зан чанараа өөрчлөх гэж эрж хайлгүйгээр Бурханы үгийн өнгөц талуудыг дуулгавартай дагах төдий байх нь Бурханы зүрх сэтгэлийн дагуу байх биш юм. Бурханд дуулгавартай байх болон Бурханы ажилд захирагдах нь яг адилхан юм. Бурханд л захирагдаад, Түүний ажилд захирагддаггүй хүмүүсийг дуулгавартайд тооцож болохгүй, үнэнээсээ захирагддаггүй атлаа гаднаа зулгуйдан зусарддаг хүмүүсийг бүр ч тооцож болохгүй. Бурханд үнэнээсээ захирагддаг хүмүүс бүгдээрээ ажлаас нь хүртэж, Бурханы зан чанар болон ажлын талаарх ойлголтод хүрдэг. Зөвхөн ийм л хүмүүс Бурханд үнэхээр захирагддаг. Ийм хүмүүс шинэ ажлаас шинэ мэдлэг олж авч, мөн үүнээс шинэ өөрчлөлтийг туулж чаддаг. Зөвхөн ийм хүмүүсийг л Бурхан сайшаадаг; ийм хүмүүс л төгс болгуулдаг, зан чанараа өөрчилсөн хүмүүс билээ. Бурханы сайшаадаг хүмүүс нь Бурханд, түүнчлэн Түүний үг болон ажилд баяртайяа захирагддаг хүмүүс юм. Зөвхөн ийм хүмүүс л зөв; ийм хүмүүс л Бурханыг чин сэтгэлээсээ хүсэж, Бурханыг чин сэтгэлээсээ эрж хайдаг. Аман дээрээ л Бурханд итгэдгээ ярихаас биш, мөн чанартаа Түүнийг хараадаг хүмүүсийн тухайд гэвэл, тэд нар бол баг зүүж, могойн хор агуулсан, хамгийн хар санаатай хүмүүс юм. Эрт орой хэзээ нэгэн цагт энэ адгийн амьтдын бузар багийг хуу татаж хаяна. Энэ өнөөдөр хийгдэж буй ажил бус уу? Хорон муу хүмүүс үргэлж хорон муу байх бөгөөд шийтгэлийн өдрөөс хэзээ ч зугтахгүй. Сайн хүмүүс ямагт сайн байх бөгөөд Бурханы ажил төгсгөлдөө ирэхэд илчлэгдэнэ. Хорон муу хүмүүсийн нэг нь ч зөв шударга гэж тооцогдохгүй, зөв шударга хүмүүсийн нэг нь ч хорон муу гэж тооцогдохгүй. Ямар ч хүн хилсээр яллагдан зогсохыг Би зөвшөөрнө гэж үү?

Амь чинь ахиж дэвшихийн хэрээр чи үргэлж шинэ оролттой, илүү өндөр, шинэ мэдлэг ухаантай байх ёстой ба энэ нь алхам бүрд гүнзгийрч байдаг. Энэ нь бүх хүний орох ёстой зүйл юм. Ярилцсанаар, сургаал сонссоноор, Бурханы үгийг уншсанаар, эсвэл тодорхой хэрэг явдлыг зохицуулснаар чи шинэ мэдлэг ухаан, шинэ гэгээрэл олж авч, хуучны дүрмээр, хуучин цагт амьдрахгүй, үргэлж шинэ гэрэлд амьдрах ба Бурханы үгээс гажихгүй. Үүнийг зөв замд орох гэж хэлдэг. Аль нэг өнгөцхөн түвшинд төлөөс төлөөд нэмэргүй. Бурханы үг өдрөөс өдөрт улам өндөр хүрээнд орж өдөр бүр шинэ зүйлс гарч ирдэг. Хүн ч бас өдөр бүр шинэ оролт хийх ёстой. Бурхан яринга хэлсэн бүхнээ биелүүлдэг, чи хөл нийлүүлж чадахгүй бол ард хоцорно. Чи залбиралдаа илүү гүн орох ёстой; Бурханы үгийг идэж, уухаа тасалдуулж болохгүй. Хүлээн авдаг гэгээрэл, гэрэлтүүлэлтээ гүнзгийрүүл, тэгвэл үзэл, төсөөлөл чинь аажмаар багасах ёстой. Чи шүүмжээ сайжруулах ёстой, чамд юу ч тулгарсан бай, энэ талаар өөрийн гэсэн бодол, үзэл бодолтой байх ёстой. Сүнсэн дэх зарим зүйлийг ойлгосноор чи гадаад зүйлсийн талаар мэдэж авч,

аливаа асуудлын мөн чанарыг ухаж ойлгох ёстой. Хэрвээ чи эдгээрээр зэвсэглээгүй бол чуулганыг яаж удирдаж чадах юм бэ? Хэрвээ чи ямар ч бодит байдал, хэрэгжүүлэлтийн замгүйгээр зөвхөн бичиг үсэг, хоосон сургаалын талаар ярьдаг бол хэсэгхэн хугацаанд л хийж дөнгөнө. Шинэ итгэгчдэд ярихад энэ нь бага зэрэг боломжийн байж магадгүй боловч хэсэг хугацааны дараа шинэ итгэгчид зарим нэг бодит туршлагатай болох үед чи тэднийг хангаж чадахаа болино. Тэгэхээр чи Бурханаар ашиглуулахад яаж тохирох юм бэ? Шинэ гэгээрэлгүйгээр чи ажиллаж чадахгүй. Шинэ гэгээрэлгүй хүмүүс нь яаж туршлагажихаа мэддэггүй хүмүүс бөгөөд ийм хүмүүс хэзээ ч шинэ мэдлэг, шинэ туршлага олж авдаггүй. Мөн амийг хангах асуудлын тухайд гэвэл, тэд өөрсдийн үүргийг хэзээ ч гүйцэтгэж чадахгүй, бас Бурхан ашиглахад тохиромжтой болж ч чадахгүй. Ийм төрлийн хүн бол ямар ч хэрэггүй, гологдол төдий юм. Үнэндээ ийм хүмүүс ажил дахь үүргээ огт гүйцэтгэх чадваргүй, бүгд ямар ч хэрэггүй амьтад байдаг. Тэд үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаад зогсохгүй, үнэндээ чуулганд ихээхэн хэрэггүй дарамт учруулдаг. Энэ “эрхэм өвгөдийг” яаравчлан чуулганаас яв, тэгвэл бусад хүн чамайг харах хэрэггүй болно гэж Би шавдуулдаг. Ийм хүмүүс шинэ ажлын талаар ямар ч ойлголтгүй боловч тоймгүй их үзлээр дүүрэн байдаг. Тэд чуулганд ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй; харин ч хутган үймүүлж, газар сайгүй сөрөг байдлыг түгээж, тэр ч байтугай элдэв төрлийн буруу хэрэг хийж, чуулганд үймээн тарьж, тэгснээр ялган таних чадвар дутмаг хүмүүсийг төөрөлдүүлж, будилуулдаг. Энэ амьд диаволууд, энэ ёрын муу сүнснүүд чуулганаас аль болох хурдан явах ёстой, чамаас болж чуулган сүйдэх вий. Чи өнөөдрийн ажлаас айдаггүй байж болно, гэхдээ маргаашийн зөвт шийтгэлээс айхгүй байна гэж үү? Чуулганд бусдыг сорон мөлждөг маш олон хүн, бас Бурханы хэвийн ажилд саад хийх гэж оролддог асар олон чоно бий. Эдгээр нь бүгдээрээ чөтгөрийн хааны явуулсан чөтгөрүүд, мэдлэггүй хурганuудыг залгих гэж оролддог хэрцгий чононууд юм. Эдгээр хүн гэгчийг хөөн зайлуулахгүй бол тэд чуулган дахь шимэгч хорхой, тахил цөлмөдөг хивэн хорхой болно. Энэ жигшмээр, мунхаг, адгийн, ой гутам өт хорхойнууд шийтгэгдэх өдөр эрт орой хэзээ нэг цагт ирэх л болно!

ХААНЧЛАЛЫН ЭРИН ҮЕ БОЛ ҮГИЙН ЭРИН ҮЕ ЮМ

Хаанчлалын эрин үед Бурхан үг ашиглан шинэ эрин үеийг эхлүүлж, Өөрийн ажилладаг арга барилыг өөрчилж, бүхий л эрин үеийн ажлыг хийдэг. Энэ нь Үгийн эрин үед Бурханы ажилладаг зарчим билээ. Тэрээр өөр өөр өнцгөөс ярихын тулд махбод болсон, ингэснээр хүн Үг махбодоор илэрсэн Бурханыг үнэхээр харж, Түүний мэргэн ухаан, гайхалтай байдлыг нүдээр харж чадах байв. Хүнийг байлдан дагуулж, төгс болгож, таягдан хаях зорилгод илүү сайн хүрэхийн тулд ийм ажил хийгддэг ба энэ нь Үгийн эрин үед ажиллахдаа үг ашиглахын жинхэнэ утга учир юм.

Эдгээр үгээр дамжуулан хүмүүс Бурханы ажил, Бурханы зан чанар, хүний мөн чанар болон хүн юунд орох учиртайг мэдэж авдаг. Үгийн эрин үед Бурханы хийхийг хүсдэг ажил үгээр дамжуулан бүхэлдээ биелдэг. Эдгээр үгээр хүмүүсийг илчилж, таягдан хаяж, шалгадаг. Хүмүүс Бурханы үгийг харж, эдгээр үгийг сонсож, эдгээр үгийн оршин тогтнолыг танин мэдсэн. Үүний үр дүнд тэд Бурханы оршин тогтнол, Бурханы бүхнйг чадагч байдал, мэргэн ухаан, мөн түүнчлэн хүнийг гэх Бурханы хайр, хүнийг аврах Түүний хүсэлд итгэх болсон. “Үг” хэмээх үг энгийн, жирийн байж болох ч бие махбодтой болсон Бурханы амнаас гардаг үг орчлон ертөнцийг донсолгож, хүмүүсийн зүрх сэтгэл, үзэл, хуучин зан чанарыг өөрчилж, бүхий л дэлхий ертөнцийн харагддаг байсан байдлыг өөрчилдөг. Эрин үеүдийн туршид өнөөдрийн Бурхан л ийм маягаар ажилласан бөгөөд зөвхөн Тэр л ийнхүү ярьж, хүнийг ингэж авардаг. Энэ мөчөөс эхлээд хүн Бурханы үгийн удирдамж дор амьдарч, Түүний үгээр хариулуулж, хангагддаг. Хүмүүс Бурханы үгийн ертөнцөд, Бурханы үгийн хараал болон ерөөл дотор амьдардаг бөгөөд Түүний үгийн шүүлт, гэсгээлт дор амьдарч эхэлсэн хүмүүс бүр ч олон бий. Эдгээр үг болон энэ ажил бүгд хүний авралын төлөө, Бурханы хүслийг биелүүлэхийн төлөө, хуучин дэлхий ертөнцийн анхдагч төрхийг өөрчлөхийн төлөө байдаг. Бурхан үг ашиглан дэлхийг бүтээсэн, орчлон ертөнц дахины хүмүүсийг үг ашиглан удирддаг бөгөөд тэднийг үгээр байлдан дагуулж, авардаг. Эцэст нь Тэр бүхий л хуучин ертөнцийг төгсгөхийн тулд үг ашиглаж, улмаар удирдлагын төлөвлөгөөгөө бүхэлд нь гүйцэлдүүлнэ. Хаанчлалын эрин үеийн туршид Өөрийн ажлыг хийж, ажлынхаа үр дүнд хүрэхийн тулд Бурхан үг ашигладаг. Тэрээр гайхамшиг болон хүчит үйлс үзүүлдэггүй, харин ердөө үгээр дамжуулан ажлаа хийдэг. Эдгээр үгээс болж хүн тэжээгдэн хангагдаж, мэдлэг болон жинхэнэ туршлага олж авдаг. Үгийн эрин үед хүн үнэхээр гойд их ерөөгдсөн. Хүн бие махбодын ямар ч шаналал амсдаггүй ба зүгээр л Бурханы үгийн элбэг дэлбэг хангалтыг эдэлдэг; тэр сохроор эрж хайж, сохроор бэдрэх шаардлагагүйгээр тайвнаар Бурханы илрэлтийг харж, Өөрийнхөө амаар ярихыг нь сонсож, Түүний хангадаг зүйлийг хүлээн авч, ажлаа биечлэн хийж байгааг нь хардаг. Эдгээр нь өмнөх эрин үеүдийн хүмүүсийн эдэлж чадаагүй зүйлс, хэзээ ч хүртэж байгаагүй ерөөл юм.

Бурхан хүнийг бүрэн төгс болгохоор шийдсэн бөгөөд Тэр ямар өнцгөөс ярих нь хамаагүй, бүгд хүмүүсийг төгс болгохын төлөө байдаг. Сүнсний өнцгөөс ярьсан үгийг хүмүүс ойлгоход хэцүү байдаг; тэд хэрэгжүүлэлтийн замыг олох аргагүй байдаг, учир нь тэдний ойлгох чадвар хязгаарлагдмал. Бурханы ажил өөр өөр үр дүнд хүрдэг бөгөөд ажлын алхам бүрийг хийхдээ Тэр Өөрийн гэсэн зорилготой байдаг. Түүнчлэн, Тэрээр өөр өөр өнцгөөс ярих шаардлагатай, учир нь ингэснээр л хүнийг төгс болгож чадна. Хэрвээ Тэр зөвхөн Сүнсний өнцгөөс ярьдаг байсан бол Бурханы ажлын энэ үе шатыг гүйцэлдүүлэх аргагүй байх байлаа. Түүний ярианы өнгөнөөс энэ бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгохоор шийдсэнийг нь чи харж болно. Тэгвэл, төгс болгуулахыг хүсдэг хүн нэг бүрийн эхний алхам нь юу байх ёстой вэ?

Юун түрүүнд, Бурханы ажлыг мэдэх ёстой. Өнөөдөр, Бурханы ажилд шинэ арга барил нэвтэрсэн; эрин үе шилжиж, Бурханы ажлын арга барил ч өөрчлөгдсөн ба Бурханы үг хэлдэг арга барил өөр болсон. Өнөөдөр Түүний ажлын арга барил өөрчлөгдөөд зогсоогүй, эрин үе ч бас өөрчлөгдсөн. Одоо үе бол Хаанчлалын эрин үе. Түүнчлэн энэ нь Бурханыг хайрлах эрин үе юм. Мөн энэ бол Мянган жилийн хаанчлалын эрин үеийн урьтал—бас Үгийн эрин үе бөгөөд хүнийг төгс болгохын тулд Бурхан олон янзын арга барилаар ярьж, хүнийг хангахын тулд өөр өөр өнцгөөс ярьдаг. Мянган жилийн хаанчлалын эрин үед ормогц хүнийг төгс болгохын тулд Бурхан үг ашиглаж эхлэн, хүнийг амь-бодит байдалд оруулж, зөв зам руу хөтөлнө. Хүн Бурханы ажлын маш олон алхмыг туулаад Бурханы ажил өөрчлөгдөхгүй хэвээр үлддэггүй, харин тасралтгүй өөрчлөгдөж, гүнзгийрч байгаа гэдгийг харсан юм. Хүмүүс үүнийг маш удаан хугацаанд туулсны дараа уг ажил удаа дараа хувирч, ахин дахин өөрчлөгдсөн. Гэхдээ энэ нь хэчнээн ч их өөрчлөгдсөн бай, хүмүүст аврал авчрах Бурханы зорилгоос хэзээ ч хазайдаггүй. Арван мянган өөрчлөлт тууллаа ч гэсэн, анхдагч зорилгоосоо хэзээ ч хазайдаггүй. Бурханы ажлын арга барил яаж ч өөрчлөгдлөө гэсэн, энэхүү ажил үнэнээс юм уу амиас хэзээ ч холддоггүй. Ажиллах арга барилын өөрчлөлт нь ердөө ажлын хэлбэр болон Бурханы ярих өнцгийн өөрчлөлттэй хамаатай байдаг; Бурханы ажлын гол зорилго огт өөрчлөгддөггүй. Бурханы хоолойны өнгө болон ажлын арга барил дахь өөрчлөлт нь үр дүнд хүрэхийн тулд хийгддэг. Дуу хоолойн өнгөний өөрчлөлт нь ажлын ар дахь зорилго юм уу зарчим өөрчлөгдсөн гэсэн үг биш. Хүмүүс голчлон амийг эрж хайхын тулд л Бурханд итгэдэг; хэрвээ чи Бурханд итгэдэг атлаа амийг эрж хайдаггүй, эсвэл үнэнийг юм уу Бурханы талаарх мэдлэгийг эрэлхийлдэггүй бол энэ нь Бурханд итгэх итгэл биш! Хаан болохын тулд хаанчлалд орохоор эрэлхийлсээр байх нь бодитой юу? Амийг эрж хайснаар Бурханыг гэх жинхэнэ хайранд хүрэх нь л бодит байдал; үнэнийг эрж хайж, хэрэгжүүлэх нь бүгд бодит байдал билээ. Бурханы үгийг уншиж, эдгээр үгийг туулснаар чи бодит туршлагаараа Бурханы тухай мэдлэгийг мэдэж авна, үнэхээр эрэлхийлэх гэдэг нь энэ юм.

Одоо бол Хаанчлалын эрин үе. Энэхүү шинэ эрин үед орсон эсэх чинь Бурханы үгийн бодит байдалд орсон эсэхээр чинь, мөн Түүний үг чиний амь-бодит байдал болсон эсэхээс хамаардаг. Бурханы үг хүн бүрд мэдэгддэг болохоор эцэстээ бүх хүн үгийн ертөнцөд амьдарч, Бурханы үг хүн бүрийг дотроос нь гэгээрүүлж, гэрэлтүүлнэ. Хэрвээ чи энэ хугацаанд Бурханы үгийг уншихдаа хайхрамжгүй байж, Түүний үгийг огт сонирхдоггүй бол байр байдал чинь буруу байгааг энэ нь харуулдаг. Хэрвээ чи Үгийн эрин үед орж чадахгүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллахгүй; хэрвээ чи энэ эрин үед орсон бол Тэр Өөрийн ажлыг хийнэ. Ариун Сүнсний ажлыг олж авахын тулд чи Үгийн эрин үеийн эхлэлд юу хийж болох вэ? Энэ эрин үед Бурхан дараах баримтыг та нарын дунд гүйцэлдүүлнэ: хүн бүр Бурханы үгийг амьдран харуулаад, үнэнийг хэрэгжүүлж чаддаг байж, Бурханыг чин

сэтгэлээсээ хайрлана; бүх хүн Бурханы үгийг үндэс суурь, бодит байдлаа болгон ашиглаж, Бурханыг хүндлэх зүрх сэтгэлтэй байна; Бурханы үгийг хэрэгжүүлснээр хүн Бурхантай хамт хааны эрх мэдлийг эзэмшинэ. Энэ бол Бурханы биелүүлэх ажил юм. Чи Бурханы үгийг уншихгүй байж чадах уу? Өнөөдөр, Бурханы үгийг уншихгүйгээр ганц, хоёр хонож ч чадахгүй мэт санадаг олон хүн бий. Тэд Түүний үгийг өдөр бүр унших хэрэгтэй байдаг бөгөөд цаг зав гарахгүй бол Түүний үгийг сонсох нь хангалттай байдаг. Энэ бол хүмүүст Ариун Сүнсний өгдөг мэдрэмж бөгөөд тэдний зүрх сэтгэлийг хөдөлгөж эхэлдэг Түүний арга зам юм. Өөрөөр хэлбэл, Тэр хүмүүсийг үгээр захирдаг, ингэснээр тэд Бурханы үгийн бодит байдалд орж чаддаг. Хэрвээ Бурханы үгийг идэж, уулгүй ганц хоносны дараа дотор чинь харанхуйлж, цангаж, тэсэхийн аргагүй санагдаж байвал Ариун Сүнс чиний сэтгэлийг хөдөлгөсөн бөгөөд Тэр чамаас нүүр буруулаагүйг энэ нь харуулдаг. Тэгвэл чи энэ урсгалд байгаа нэгэн юм. Харин Бурханы үгийг идэж, уулгүйгээр ганц хоёр хоносны дараа чамд юу ч мэдрэгдэхгүй, огт цангахгүй байвал, мөн сэтгэл чинь огтхон ч хөдлөхгүй бол Ариун Сүнс чамаас нүүр буруулсныг энэ нь харуулдаг. Тэгвэл чиний дотоод байдалд ямар нэг юм буруу байна гэсэн үг; чи Үгийн эрин үед ороогүй бөгөөд хоцорч үлдсэн хүмүүсийн нэг юм. Бурхан хүмүүсийг захирахдаа үг ашигладаг; Бурханы үгийг идэж, уувал чамд сайхан санагддаг ба хэрвээ идэж уухгүй бол чамд дагах ямар ч зам байдаггүй. Бурханы үг нь хүмүүсийн хоол, мөн тэднийг хөдөлгөгч хүч болдог. Библид “Хүн зөвхөн талхаар амьдардаггүй, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдардаг” (Матай 4:4) гэсэн байдаг. Бурхан өнөөдөр энэ ажлыг биелүүлж, энэ баримтыг та нар дээр гүйцэлдүүлнэ. Урьд нь хүмүүс Бурханы үгийг уншилгүй олон өдөр явсан ч ердийнхөөрөө хооллож, ажиллаж чаддаг байсан мөртөө яагаад өнөөдөр тэгдэггүй юм бэ? Энэ эрин үед Бурхан бүхнийг захирахын тулд голчлон үг ашигладаг. Бурханы үгээр хүн шүүгдэж, төгс болгуулж, эцэстээ хаанчлал руу хүргэгддэг. Ялангуяа Хаанчлалын эрин үед зөвхөн Бурханы үг л хүний амийг хангаж чадна, Бурханы үг л хүнд гэрэл болон хэрэгжүүлэлтийн замыг өгч чадна. Чи Бурханы үгийн бодит байдлаас холдолгүйгээр өдөр бүр Түүний үгийг идэж, ууж байгаа цагт Бурхан чамайг төгс болгож чадна.

Амийг эрэлхийлэх нь яарч болдог зүйл биш; амийн өсөлт ганц хоёрхон хоногийн дотор явагддаггүй. Бурханы ажил хэвийн, бодитой байдаг бөгөөд зайлшгүй туулах ёстой үйл явц гэж бий. Есүс бие махбодтой болж цовдлолын ажлаа гүйцэлдүүлэхэд гучин гурван жил хагас шаардагдсан—хүнийг ариусгаж, түүний амийг өөрчлөх нь туйлын хэцүү ажил биш үү? Бурханыг илэрхийлдэг хэвийн хүнийг бий болгох нь тийм ч амаргүй. Ялангуяа агуу улаан лууны үндэстэнд төрсөн, хэв чанар муутай хүмүүсийн хувьд ийм байдаг бөгөөд удаан хугацааны Бурханы үг болон ажил шаардагддаг. Иймээс үр дүн харах гэж бүү тэсэн яд. Чи Бурханы үгийг идэж, уухдаа идэвх санаачилгатай байж, Бурханы үгэнд илүү их хичээл чармайлт гаргах ёстой. Түүний үгийг уншиж дуусах үедээ бодитоор хэрэгжүүлж, Бурханы үгээс мэдлэг, ойлголт, ялган таних чадвар, мэргэн ухаанаа нэмэгдүүлж чаддаг байх

ёстой. Үүгээр дамжуулан чи өөрийн мэдэлгүй өөрчлөгдөнө. Хэрвээ чи Бурханы үгийг идэж уух, унших, мэдэж авах, мэдэрч туулах, хэрэгжүүлэхийг өөрийн зарчим болгож чаддаг бол өөрийн мэдэлгүй төлөвшинө. Бурханы үгийг уншсаныхаа дараа ч хэрэгжүүлж чаддаггүй гэж хэлдэг хүмүүс бий. Чи юунд яарна вэ? Тодорхой биеийн хэмжээнд хүрэх үедээ чи Түүний үгийг хэрэгжүүлж чадна. Дөрөв юм уу таван настай хүүхэд, эцэг эхийгээ тэжээж, хүндэлж чаддаггүй гэж хэлнэ гэж үү? Одоогийн биеийн хэмжээ чинь хэр том болохыг чи мэдэх ёстой. Хэрэгжүүлж чадах зүйлээ хэрэгжүүл, Бурханы удирдлагыг үймүүлдэг нэгэн байхаас зайлсхий. Зүгээр л Бурханы үгийг идэж уу, мөн одоогоос эхлээд үүнийг зарчмаа болго. Бурхан чамайг бүрэн төгс болгож чадах эсэхэд одоохондоо бүү санаа зов. Үүнийг хараахан бүү судал. Бурханы үгийг аваад зүгээр л идэж уу, тэгвэл Бурхан чамайг бүрэн төгс болгох нь гарцаагүй. Гэхдээ Түүний үгийг идэж уухдаа баримтлах ёстой зарчим гэж бий. Сохроор бүү хий. Бурханы үгийг идэж уухдаа нэг талаар, өөрийн мэдэж авах ёстой үгийг—өөрөөр хэлбэл, үзэгдэлтэй холбоотой үгийг эрж хай—нөгөөтээгүүр бодитоор хэрэгжүүлэх ёстой буюу орох ёстой үгийг эрж хай. Нэг тал нь мэдлэгтэй хамаатай, нөгөө нь орохтой холбоотой. Хоёуланг нь ухаармагцаа—юуг мэдэх ёстой, юуг хэрэгжүүлэх ёстойгоо ухаарсан үедээ чи Бурханы үгийг хэрхэн идэж, уухаа мэднэ.

Цаашид, Бурханы үгийн тухай ярих нь чиний ярих зарчим байх ёстой. Ердийн үед цугларахдаа та нар Бурханы үгийн тухай нөхөрлөж, Бурханы үгийг ярианыхаа гол агуулга болгон авч үзэж, эдгээр үгийн талаар юу мэддэг, Түүний үгийг хэрхэн хэрэгжүүлдэг, Ариун Сүнс хэрхэн ажилладаг талаар нөхөрлөх ёстой. Бурханы үгийг нөхөрлөж байгаа цагт Ариун Сүнс чамайг гэрэлтүүлнэ. Бурханы үгийн ертөнцийг бий болгоход хүний хамтын ажиллагаа шаардлагатай. Хэрвээ чи үүнд орохгүй бол Бурхан ажиллах ямар ч аргагүй байх болно; хэрвээ чи амаа хамхиад, Түүний үгийн талаар ярьдаггүй бол Бурхан чамайг гэрэлтүүлэх ямар ч аргагүй. Чи завгүй байгаа л биш бол Бурханы үгийн тухай ярь, дэмий бүү чалч! Өөрийн амьдралыг Бурханы үгээр дүүргэ—тэр үед л чи үнэн сүсэгт итгэгч болно. Нөхөрлөл чинь өнгөц байсан ч зүгээр. Өнгөц гэж үгүй бол гүн гэж үгүй. Үйл явц байх ёстой. Дадлагаараа дамжуулан чи чам дээрх Ариун Сүнсний гэрэлтүүлэлтийг ухаарч, Бурханы үгийг хэрхэн үр ашигтайгаар идэж уухаа ухаардаг. Хэсэг хугацаанд судалсныхаа дараа чи Бурханы үгийн бодит байдал руу орно. Хамтран ажиллахаар шийдсэн л бол чи Ариун Сүнсний ажлыг хүлээн авч чадна.

Бурханы үгийг идэж уух зарчмуудын нэг нь мэдлэгтэй, нөгөө нь оролттой холбоотой. Чи аль үгийг мэдэж авах ёстой вэ? Үзэгдэлтэй холбоотой үгийг мэдэж авах ёстой (жишээлбэл, Бурханы ажил одоо ямар эрин үед орсон, Бурхан одоо юу биелүүлэхийг хүсдэг, бие махбодтой болох гэж юу болох гэх зэрэг үг; энэ бүхэн нь үзэгдэлтэй холбоотой). Хүний орох ёстой зам гэдэг нь юуг хэлж байна вэ? Энэ нь хүний хэрэгжүүлж, орох ёстой Бурханы үгийг хэлдэг. Дээр буй зүйл бол Бурханы үгийг идэж уухын хоёр тал юм. Одоогоос эхлээд ийм маягаар Бурханы үгийг идэж

уу. Хэрвээ чи үзэгдэлтэй хамаатай үгийг тодорхой ойлгочихвол цаг үргэлж уншаад байх хэрэггүй. Харин зүрх сэтгэлээ хэрхэн Бурхан руу эргүүлэх, Бурханы өмнө зүрх сэтгэлээ хэрхэн тайван байлгах, махан биеийг хэрхэн хаях гэх мэт оролтын талаарх үгийг илүү их идэж уух нь хамгийн чухал юм. Эдгээр нь чиний хэрэгжүүлэх ёстой зүйл мөн. Бурханы үгийг хэрхэн идэж уухаа мэдэхгүй бол жинхэнээсээ нөхөрлөх боломжгүй. Түүний үгийг хэрхэн идэж уухаа мэдэж, гол зүйлийг нь ухаармагц нөхөрлөл чинь чөлөөтэй болох ба ямар ч асуудал гарлаа гэсэн чи нөхөрлөж, бодит байдлыг ухаарч чадна. Бурханы үгийн талаар нөхөрлөхдөө бодит байдалгүй байвал чи гол зүйлийг ухааараагүй бөгөөд Бурханы үгийг хэрхэн идэж уухаа мэддэггүйг чинь энэ нь харуулдаг. Зарим хүнд Бурханы үгийг унших нь залхмаар санагддаг ба энэ нь хэвийн байдал биш. Бурханы үгээс хэзээ ч залхахгүй байж, үргэлж үүгээр цангаж, Бурханы үгийг үргэлж сайн гэж бодох нь хэвийн байдал юм. Үнэхээр орсон хүн Бурханы үгийг ингэж идэж уудаг. Бурханы үг дэндүү бодитой агаад хүний орох ёстой яг тэр зүйл мөн гэдгийг мэдрэх үед чинь; Түүний үг хүнд асар их тустай, ашигтай бөгөөд хүний амийн хангалт мөн гэдгийг мэдрэх үед чинь—Ариун Сүнс чамд ийм мэдрэмжийг өгдөг бөгөөд Ариун Сүнс чамайг хөдөлгөдөг. Энэ нь Ариун Сүнс чам дээр ажиллаж байгаа ба Бурхан чамаас нүүр буруулаагүй гэдгийг нотолдог. Бурхан үргэлж үг хэлж байгааг хараад зарим хүн Түүний үгээс залхаж, энийг уншсан ч бай, үгүй ч бай ямар ч ялгаагүй гэж боддог—энэ нь хэвийн байдал биш. Тэдэнд бодит байдалд орохоор цангадаг зүрх сэтгэл байдаггүй бөгөөд тийм хүмүүс төгс болгуулах гэж шимтдэггүй, мөн үүнд ач холбогдол өгдөггүй. Бурханы үгээр цангахгүй байгаа бол хэвийн бус байдалтай байгааг чинь энэ нь харуулдаг. Урьд нь, Бурхан чамаас нүүр буруулсан эсэхийг, дотроо амар тайван байгаа эсэх болон таашаал мэдэрсэн эсэхээр чинь тодорхойлдог байсан. Одоо бол, Бурханы үгээр цангадаг эсэх, Түүний үгийг бодит байдлаа болгосон эсэх, чи үнэнч эсэх, мөн Бурханы төлөө чадах бүхнээ хийж чаддаг эсэх чинь гол түлхүүр нь юм. Өөрөөр хэлбэл, хүн Бурханы үгийн бодит байдлаар үнэлэгддэг. Бурхан Өөрийн үгийг бүх хүн рүү чиглүүлдэг. Хэрвээ чи үүнийг уншихыг хүсдэг бол Тэр чамайг гэгээрүүлнэ, харин чи хүсэхгүй бол Тэр чамайг гэгээрүүлэхгүй. Зөвт байдлаар өлсөж, цангадаг, Өөрийг нь эрж хайдаг хүмүүсийг Бурхан гэгээрүүлдэг. Үгийг нь уншсаны дараа ч гэсэн Бурхан өөрсдийг нь гэгээрүүлээгүй гэж зарим хүн хэлдэг. Гэхдээ чи эдгээр үгийг ямархуу байдлаар уншсан бэ? Хэрвээ чи морин дэл дээрээс цэцэгс харж буй хүнтэй адилаар Түүний үгийг уншиж, бодит байдалд ямар ч ач холбогдол өгөөгүй бол Бурхан чамайг гэгээрүүлж яаж чадах юм бэ? Бурханы үгийг нандигнадаггүй хүн яаж Түүгээр төгс болгуулж чадах юм бэ? Хэрвээ чи Бурханы үгийг нандигнадаггүй бол чамд үнэн ч байхгүй, бодит байдал ч байхгүй байх болно. Хэрвээ чи Түүний үгийг нандигнадаг бол үнэнийг хэрэгжүүлж чадна; тэр үед л чи бодит байдлыг эзэмшинэ. Ийм учраас чи завтай ч бай, үгүй ч бай, орчин нөхцөл таатай ч бай, үгүй ч бай, шалгагдаж байгаа ч бай, үгүй ч бай цаг ямагт Бурханы үгийг идэж уух ёстой. Ерөнхийдөө, Бурханы үг бол хүний оршин тогтнолын суурь

юм. Түүний үгээс хэн ч салж чадахгүй, харин өдөрт гурван хоол иддэг шигээ Түүний үгийг идэх ёстой. Бурханаар төгс болгуулж, авхуулах нь тийм амархан гэж үү? Чи одоо ойлгодог ч бай, үгүй ч бай, мөн Бурханы ажлыг тодорхой харсан ч бай, үгүй ч бай Бурханы үгийг аль болох их идэж уух ёстой. Энэ бол идэвх санаачилгатайгаар орж байгаа хэрэг юм. Бурханы үгийг уншсаны дараа орж чадах зүйлсээ яаравчлан хэрэгжүүлж, чадахгүй зүйлээ түр хойш тавь. Эхэндээ чиний ойлгож чадахгүй Бурханы үг их байж болох ч хоёр, гурван сарын дараа, магадгүй бүр жилийн дараа чи ойлгоно. Яагаад тэр вэ? Учир нь Бурхан хүмүүсийг ганц, хоёрхон хоногт төгс болгож чадахгүй. Ихэнх тохиолдолд, Түүний үгийг унших үедээ чи тэр дороо ойлгохгүй байж магадгүй. Тэр үед энэ нь ердөө бичвэрээс цаашгүй харагдаж магад; чи тэдгээрийг хэсэг хугацаанд туулсныхаа дараа л ойлгож чадна. Бурхан маш ихийг ярьсан болохоор Түүний үгийг идэж, уухын тулд чи чадах бүхнээ хийх ёстой, дараа нь чи өөрийн мэдэлгүй ойлгож авах бөгөөд нэг л мэдэхэд Ариун Сүнс чамайг гэгээрүүлнэ. Ариун Сүнс хүнийг гэгээрүүлэх үедээ хүнд ихэвчлэн мэдэгддэггүй. Цангаж, эрж хайх үед чинь Тэр чамайг гэгээрүүлж, залж чиглүүлдэг. Ариун Сүнсний ажилладаг зарчим нь чиний идэж уудаг Бурханы үгэнд төвлөрдөг. Бурханы үгэнд ямар ч ач холбогдол өгдөггүй, Түүний үгэнд үргэлж өөр хандлага баримталдаг—Түүний үгийг уншсан ч бай, үгүй ч бай ялгаагүй гэж мунгинан боддог бүх хүн бол бодит байдлыг эзэмшдэггүй хүмүүс юм. Ийм хүнээс Ариун Сүнсний ажлыг ч, Түүний гэгээрлийг ч харах аргагүй. Иймэрхүү хүмүүс бол сургаалт үлгэрийн[a] Нангуо гуайтай адил, бусдын хүчээр амьдардаг дүр үзүүлэгчид юм.

Бурханы үгийг бодит байдлаа болгохгүй бол чамд ямар ч бодитой биеийн хэмжээ байдаггүй. Шалгагдах цаг ирэхэд чи гарцаагүй унана, тэр үед жинхэнэ биеийн хэмжээ чинь илчлэгдэнэ. Харин бодит байдалд орохоор байнга эрж хайдаг хүмүүс шалгалтад өртөх үедээ Бурханы ажлын зорилгыг ойлгож авдаг. Мөс чанартай бөгөөд Бурханаар цангадаг хүн Бурханы хайрыг хариулахын тулд бодитой үйлдэл хийх ёстой. Бодит байдал эзэмшээгүй хүмүүс ялимгүй хэрэг явдлын өмнө ч бат зогсож чадахгүй. Бодитой биеийн хэмжээтэй болон биеийн хэмжээгүй хүмүүсийн хоорондох ялгаа энэ юм. Аль аль нь Бурханы үгийг идэж, уудаг ч яагаад зарим нь шалгалт дунд бат зогсож чаддаг байхад бусад нь зугтдаг юм бэ? Илт ялгаа бол заримд нь бодитой биеийн хэмжээ дутмаг байдаг; тэд Бурханы үгийг бодит байдлаа болгоогүй бөгөөд Түүний үг тэдний дотор үндэслээгүй. Шалгагдмагцаа тэд замынхаа төгсгөлд очдог. Тэгвэл яагаад зарим нь шалгалтуудын дунд бат зогсож чаддаг юм бэ? Учир нь тэд үнэнийг ойлгодог, үзэгдэлтэй байдаг, мөн Бурханы үг болон шаардлагыг ойлгож, улмаар шалгалтад бат зогсож чаддаг. Энэ бол бодитой биеийн хэмжээ, энэ нь бас амь юм. Зарим хүн Бурханы үгийг уншдаг боловч хэрэгжүүлдэггүй, эсвэл тэдгээрийг нухацтай авч үздэггүй; тэдгээрийг нухацтай авч үздэггүй хүмүүс хэрэгжүүлэлтэд ач холбогдол

[a] Эх бичвэрт “сургаалт үлгэрийн” гэх хэллэг байдаггүй.

өгдөггүй. Бурханы үгийг бодит байдлаа болгоогүй хүмүүс бол бодитой биеийн хэмжээгүй бөгөөд тийм хүмүүс шалгалтад бат зогсож чадахгүй.

Бурханы үг гарах үед чи даруй хүлээн авч, идэж, уух ёстой. Хэчнээн ихийг ойлгодог чинь хамаагүй, чиний тууштай баримтлах ёстой нэг үзэл бодол бол Түүний үгийг идэж, ууж, мэдэж, хэрэгжүүлэх явдал юм. Энэ бол чиний хийж чаддаг байх ёстой зүйл билээ. Биеийн хэмжээ чинь хэр том болж болох талаар бүү санаа зов; Түүний үгийг идэж, уухад л анхаарлаа төвлөрүүл. Энэ бол хүний хамтран ажиллах ёстой зүйл билээ. Сүнслэг амьдрал чинь үндсэндээ Бурханы үгийг идэж уух болон тэдгээрийг хэрэгжүүлэх бодит байдалд орохоор хичээх явдал юм. Өөр ямар нэг зүйл дээр анхаарлаа төвлөрүүлэх нь чиний хэрэг биш. Чуулганы удирдагчид бүх ах, эгч нараа удирдаж, Бурханы үгийг яаж идэж уухаа мэддэг болгох ёстой. Энэ бол чуулганы удирдагч нэг бүрийн хариуцлага мөн. Тэд залуу ч бай, хөгшин ч бай, бүгд Бурханы үгийг идэж уухыг асар чухалд тооцож, Түүний үгийг зүрх сэтгэлдээ байлгах ёстой. Ийм бодит байдалд орох нь Хаанчлалын эрин үед орсон гэсэн үг юм. Өнөөдөр, ихэнх хүнд Бурханы үгийг идэж уухгүйгээр амьдарч чадахгүй гэж санагддаг бөгөөд Түүний үг цаг ямагт шинэхэн санагддаг. Энэ нь, тэд зөв замд орж эхэлж байна гэсэн үг юм. Бурхан ажлаа хийж, хүнийг хангахын тулд үг ашигладаг. Хүн бүхэн Бурханы үгийг хүсэн эрмэлзэж, Бурханы үгээр цангах үед хүмүүс Түүний үгийн ертөнцөд орно.

Бурхан асар ихийг ярьсан. Чи хэр ихийг нь мэдэж авсан бэ? Хэр их рүү нь орсон бэ? Хэрвээ чуулганы удирдагч ах, эгч нараа Бурханы үгийн бодит байдал руу замчлаагүй бол үүргээ хөсөрдүүлж, хариуцлагаа биелүүлж чадаагүй байх болно! Ойлголт чинь гүн гүнзгий юм уу өнгөц байх нь хамаагүй, ойлголтынхоо түвшнээс үл хамааран чи Түүний үгийг хэрхэн идэж, уухаа мэддэг байх ёстой, мөн Түүний үгэнд асар их анхаарал хандуулж, тэдгээрийг идэж уухын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг ойлгох ёстой. Бурхан маш ихийг ярьчхаад байхад чи Түүний үгийг идэж уухгүй, эрж хайхгүй, эсвэл хэрэгжүүлэхгүй бол үүнийг Бурханд итгэх гэж нэрлэж болохгүй. Чи Бурханд итгэдэг тул Түүний үгийг идэж ууж, Түүний үгийг туулж, Түүний үгийг амьдран харуулах ёстой. Зөвхөн үүнийг л Бурханд итгэх итгэл гэж нэрлэж болно! Чи Бурханд итгэдэг гэж амаараа хэлдэг атлаа Түүний үгийн алийг нь ч хэрэгжүүлж, бодит байдал болгож чадахгүй бол үүнийг Бурханд итгэх гэж нэрлэхгүй. Харин ч, энэ нь “өлсгөлөнгөө дарахын тулд талх хайх” явдал юм. Өчүүхэн төдий ч бодит байдал эзэмшихгүйгээр ялихгүй гэрчлэл, хэрэггүй зүйлс болон өнгөц хэрэг явдлын талаар л ярих: эдгээр нь Бурханд итгэх итгэлийг бүрдүүлдэггүй бөгөөд чи Бурханд итгэх зөв замыг ердөө ухаарсангүй. Яагаад Бурханы үгийг аль болох их идэж уух ёстой вэ? Хэрвээ Түүний үгийг идэж уухгүй, зөвхөн тэнгэрт гарахыг л хичээдэг бол энэ нь Бурханд итгэж байгаа хэрэг үү? Бурханд итгэдэг хүний хийх ёстой эхний алхам юу вэ? Бурхан ямар замаар хүнийг төгс болгодог вэ? Бурханы үгийг идэж уухгүйгээр төгс болгуулж чадах уу? Бурханы үгийг өөрийн бодит байдал болгохгүй бол чамайг хаанчлалын ард гэж үзэж болох уу? Бурханд итгэх итгэл гэдэг нь яг юу гэсэн үг вэ? Бурханд итгэгч ядаж гаднаа ааш

зан сайтай байх ёстой; хамгийн чухал нь Бурханы үгийг эзэмших явдал юм. Юу ч болж байсан чи Түүний үгээс хэзээ ч салж болохгүй. Бурханыг мэдэх, Түүний санаа зорилгыг биелүүлэх нь бүгд Түүний үгээр дамжин биелдэг. Ирээдүйд, улс үндэстэн, урсгал, шашин, салбар болгоныг Бурханы үгээр байлдан дагуулна. Бурхан шууд ярьж, бүх хүн Бурханы үгийг гартаа барьж, ийм арга замаар хүмүүс төгс болгуулна. Дотор гадна хааяагүй Бурханы үг тархана: Хүмүүс амаараа Бурханы үгийг ярьж, Бурханы үгийн дагуу хэрэгжүүлж, Бурханы үгийг дотроо хадгалж, дотор гаднагүй Бурханы үг нэвчсэн байх болно. Тийнхүү хүмүүс төгс болгуулна. Бурханы санаа зорилгыг биелүүлдэг, Түүнд гэрчлэл хийж чаддаг хүмүүс бол Бурханы үгийг бодит байдлаа болгосон хүмүүс юм.

Үгийн эрин үе буюу Мянган жилийн хаанчлалын эрин үед орох нь өнөөдөр хийгдэж буй ажил юм. Одоогоос эхлээд Бурханы үгийн талаар нөхөрлө. Бурханы үгийг идэж, ууж, туулснаар чи Бурханы үгийг амьдран харуулж чадна. Бусдыг үнэмшүүлэхийн тулд чи бодитой туршлагатай байх ёстой. Хэрвээ чи Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулж чадахгүй бол хэн ч үнэмшихгүй! Бурханы ашигладаг бүх хүн Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулж чадна. Хэрвээ чи ийм бодит байдлыг бий болгож, Бурханд гэрчлэл хийж чадахгүй бол Ариун Сүнс чиний дотор ажиллаагүй, бас чи төгс болгуулаагүй гэдгийг энэ нь харуулдаг. Энэ бол Бурханы үгийн ач холбогдол билээ. Бурханы үгээр цангадаг зүрх сэтгэл чамд байгаа юу? Бурханы үгээр цангадаг хүмүүс үнэнээр цангадаг бөгөөд зөвхөн тийм хүмүүс л Бурханаар ерөөгддөг. Ирээдүйд Бурхан бүх шашин болон бүх урсгалд илүү олон үг хэлнэ. Тэрээр та нарыг бүрэн төгс болгохын тулд эхлээд та нарын дунд үг хэлж, дуу хоолойгоороо айлдаад, дараа нь Харь үндэстнүүдийг байлдан дагуулахын тулд тэдний дунд үгээ хэлж, Өөрийн дуу хоолойгоор айлдана. Түүний үгээр дамжуулан бүгд чин сэтгэлээсээ бүрэн дүүрэн үнэмшинэ. Бурханы үг болон Түүний илчлэлээр дамжуулан хүний завхарсан зан чанар багасаж, хүний дүр төрхтэй болж, тэрслүү зан чанар нь цөөрдөг. Үг эрх мэдэлтэйгээр хүн дээр ажиллаж, Бурханы гэрэл дотор хүнийг байлдан дагуулдаг. Одоогийн эрин үед Бурханы хийдэг ажил болон Түүний ажлын эргэлтийн цэгийг бүгдийг нь Түүний үгэн дотроос олж болно. Хэрвээ чи Түүний үгийг уншдаггүй бол юу ч ойлгохгүй. Түүний үгийг идэж ууснаар, ах эгч нартайгаа нөхөрлөснөөр, өөрийн бодит туршлагаар дамжуулан чи Бурханы үгийн талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй болно. Тэр үед л чи Бурханы үгийн бодит байдлыг үнэхээр амьдран харуулж чадна.

БҮГД БУРХАНЫ ҮГЭЭР БИЕЛДЭГ

Бурхан өөр өөр эрин үеийн дагуу үгээ хэлж, ажлаа хийдэг ба өөр эрин үе бүрд өөр өөр үг хэлдэг. Бурхан дүрэмд захирагддаггүй, нэг ажлаа давтдаггүй, өнгөрсөн үеийн зүйлсийг санагалздаггүй; Тэр бол үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй

Бурхан бөгөөд өдөр бүр шинэ үг хэлдэг. Өнөөдөр баримтлах ёстой зүйлийг чи баримтлах л ёстой; энэ бол хүний хариуцлага, үүрэг билээ. Бурханы одоогийн гэрэл болон үгэнд төвлөрөн хэрэгжүүлэх нь маш чухал. Бурхан дүрэмд захирагддаггүй бөгөөд Өөрийнхөө мэргэн ухаан, бүхнийг чадагч байдлыг ил болгохын тулд олон өөр өнцгөөс ярьж чаддаг. Бурхан Сүнсний өнцгөөс ярьж байна уу, хүний өнцгөөс ярьж байна уу, эсвэл гуравдагч хүний өнцгөөс ярьж байна уу гэдэг нь хамаагүй—Бурхан бол үргэлж Бурхан байх ба хүний өнцгөөс ярьдаг байлаа гээд Түүнийг чи Бурхан биш гэж хэлж болохгүй. Бурханы ярьдаг өөр өөр өнцгөөс үүдэн зарим хүмүүсийн дунд үзэл бий болжээ. Иймэрхүү хүмүүст Бурханы тухай, мөн Түүний ажлын тухай ямар ч мэдлэг байдаггүй. Хэрвээ Бурхан үргэлж л нэг өнцгөөс яриад байвал, хүмүүс Бурханы тухай дүрэм гаргахгүй гэж үү? Бурхан хүнд ингэж авирлахыг зөвшөөрөх байсан уу? Бурхан ямар ч өнцгөөс ярьж байлаа гэсэн, Түүнд ингэх шалтгаан бий. Хэрвээ Бурхан үргэлж Сүнсний өнцгөөс ярьдаг байсан бол чи Түүнтэй харилцаж чадах байсан уу? Тиймээс Тэр заримдаа гуравдагч хүний өнцгөөс ярьж, Өөрийн үгээр чамайг хангаж, бодит байдал руу хөтөлдөг. Бурханы хийж байгаа юм бүхэн тохиромжтой байдаг. Товчоор хэлбэл, үүнийг бүгдийг нь Бурхан хийдэг бөгөөд үүнд чи эргэлзэх хэрэггүй. Тэрээр Бурхан учраас ямар ч өнцгөөс ярилаа гэсэн Бурхан хэвээрээ л байна. Энэ бол хувиршгүй үнэн. Тэр яаж ч ажилласан Бурхан хэвээр байх ба Түүний мөн чанар өөрчлөгдөхгүй! Петр Бурханыг маш их хайрладаг, Бурханы сэтгэлд яг нийцдэг хүн байсан ч Бурхан түүнийг Эзэн юм уу Христ гэж гэрчлээгүй, учир нь оршихуйн мөн чанар нь юу байна, түүгээрээ л байх ба хэзээ ч өөрчлөгдөхгүй. Өөрийнхөө ажилд Бурхан дүрэмд баригддаггүй, харин ажлаа үр дүнд хүргэж, хүнийг Өөрийнхөө тухай илүү гүнзгий мэдлэгтэй болгохын тулд янз бүрийн арга барил хэрэглэдэг. Бурханы ажиллах арга барил бүр нь хүнд Бурханыг мэдэхэд хэрэг болдог бөгөөд хүмүүсийг төгс болгох зорилготой байдаг. Тэр ажлын ямар арга барил ашиглахаас үл хамааран, бүгд л хүнийг хөгжүүлж, төгс болгох зорилго агуулдаг. Хэдийгээр Түүний ажиллах арга барилуудын нэг нь маш удаан хугацаанд үргэлжилсэн ч гэсэн энэ нь Түүнд итгэх хүний итгэлийг хатуужуулахын төлөө юм. Тиймээс та бүхэн сэтгэлдээ эргэлзэх хэрэггүй. Эдгээр нь бүгд Бурханы ажлын алхам бөгөөд та нар үүнийг дуулгавартай дагах ёстой.

Өнөөдөр яригдаж байгаа зүйл бол бодит байдал руу орох тухай юм. Тэнгэр өөд гарах тухай, хаан болж захирах тухай яриагүй байна; яригдаж байгаа бүх зүйл бодит байдал руу орохоор эрэлхийлэх тухай байдаг. Үүнээс илүү бодитой эрэл хайгуул байхгүй ба хаан болж захирах тухай ярих нь бодитой зүйл биш юм. Хүмүүс маш сониуч зантай бөгөөд өнөөдрийн Бурханы ажлыг өөрсдийн шашны үзлээр хэмжсээр байдаг. Бурханы ажиллах арга барилын маш олныг туулсан мөртөө хүн одоо хэр нь Бурханы ажлыг мэддэггүй, тэмдэг, гайхамшгийг эрж хайсаар, Бурханы үг биелсэн эсэхийг шалгаж харсаар л байдаг. Энэ нь гайхширмаар мунхаг байдал биш гэж үү? Бурханы үг биеллээ олоогүй бол Тэр бол Бурхан гэж чи итгэсээр байх

байсан уу? Өнөөдөр, чуулганы олон ийм хүн тэмдэг, гайхамшгийг олж харахаар хүлээж байгаа. Бурханы үг биелбэл Тэр Бурхан мөн; харин биелэхгүй бол Тэр Бурхан биш гэж тэд хэлдэг. Тэгвэл чи үг нь биелдэг учраас Бурханд итгэдэг үү, эсвэл Тэр бол Бурхан Өөрөө мөн учраас итгэдэг үү? Хүний Бурханд итгэх тухай үзлийг залруулах шаардлагатай! Бурханы үг биелээгүйг хараад чи зугтан оддог—энэ чинь Бурханд итгэх итгэл мөн үү? Бурханд итгэх үедээ чи бүх зүйлийг Бурханы эрхшээлд орхиж, Бурханы бүх ажлыг дуулгавартай дагах ёстой. Бурхан Хуучин Гэрээнд маш олон үг хэлсэн, тэдгээрийн аль нь биелснийг чи нүдээрээ харсан бэ? Чи өөрөө хараагүй болохоор Ехова бол жинхэнэ Бурхан биш гэж хэлж чадах уу? Олон үг биелсэн байж болох ч хүнд үнэн байхгүй, тэр юу ч ойлгодоггүй учраас үүнийг тодорхой харж чаддаггүй. Бурханы үг биелээгүй гэж санагдах үед зарим хүн зугтахыг хүсдэг. Оролдоод үз л дээ, чи зугтаж чадах эсэхээ хар. Зугтсаныхаа дараа чи эргээд ирэх л болно. Бурхан үгээрээ чамайг хянадаг, чи чуулганыг болон Бурханы үгийг орхивол чамд цааш амьдрах зам үгүй болно. Итгэхгүй байгаа бол, өөрөө оролдоод үз—зүгээр л орхиод явчхаж чадна гэж чи бодоо юу? Бурханы Сүнс чамайг хянадаг ба чи явж чадахгүй. Энэ бол Бурханы захиргааны зарлиг юм! Зарим хүн оролдоод үзэхийг хүсвэл, яах вэ, тэгж болно! Чи энэ хүнийг Бурхан биш гэж хэлдэг, тэгвэл Түүний эсрэг нүгэл үйлдээд, Түүний юу хийхийг хар. Махан бие чинь үхэхгүй, чи өөрийгөө хооллож, хувцаслах чадвартай хэвээр байж болох ч сэтгэл санааны хувьд тэвчишгүй байх болно; чи хямарч, шаналах ба үүнээс илүү зовлонтой зүйл гэж байхгүй. Хүмүүс оюун санааны тарчлаан, тамлалыг тэсэж чаддаггүй. Магадгүй чи махан биеийн зовлонг тэсэж чаддаг байж болох ч оюун санааны хямрал, удаан хугацааны тарчлалыг тэсвэрлэж огт чаддаггүй. Өнөөдөр, ямар нэг тэмдэг, гайхамшиг харж чадаагүйгээсээ болоод зарим хүн сөрөг болдог мөртөө хэчнээн сөрөг болсон ч бай, хэн ч зугтаж зүрхэлдэггүй, учир нь Бурхан хүмүүсийг үгээрээ хянадаг. Ямар нэг баримт гарч ирээгүй атал хэн ч зугтаж чаддаггүй. Эдгээр нь Бурханы үйлдэл биш гэж үү? Өнөөдөр Бурхан хүнийг амиар хангах гэж газар дэлхий дээр ирчихсэн байна. Тэр хүмүүсийн төсөөлдөг шиг, Бурхан, хүн хоёрын хоорондох энх амгалан харилцааг бататгахын тулд тэмдэг, гайхамшиг үзүүлж чамайг хуурдаггүй. Аминд анхаарлаа хандуулдаггүй, харин оронд нь Бурханы үзүүлэх тэмдэг гайхамшигт анхаардаг бүх хүн бол фарисайчууд юм! Есүсийг загалмайд цовдолсон хүмүүс нь фарисайчууд байсан. Хэрвээ чи, Бурханд итгэх өөрийн үзэл бодлын дагуу Бурханыг хэмжиж, Бурханы үг биелэхэд Түүнд итгэж, биелэхгүй бол эргэлзэн, бүр Түүнийг доромжилдог бол чи ч бас Түүнийг загалмайд цовдолж байгаа бус уу? Ийм хүмүүс өөрсдийн үүргийг умартаж, ая тухтай байдалд шунахайран зугаацдаг!

Нэг талаасаа, Бурханы ажлыг мэддэггүй нь хүний хамгийн том асуудал. Хүн үгүйсгэх хандлагагүй ч эргэлзэх хандлагатай байдаг; тэр үгүйсгэдэггүй боловч бүрэн хүлээн зөвшөөрдөггүй. Хэрвээ хүмүүс Бурханы ажлын талаар нэгд нэггүй мэдлэгтэй бол зугтахгүй. Өөр нэг асуудал нь хүн бодит байдлыг мэддэггүй.

Өнөөдөр хүн бүрийн харьцаж байгаа зүйл нь Бурханы үг л юм; үнэндээ чи ирээдүйд тэмдэг, гайхамшиг харна хэмээн бодох хэрэггүй. Би чамд илэн далангүй хэлье: Өнөөгийн үе шатанд, чиний харж чадах ганц зүйл бол Бурханы үг бөгөөд баримт байхгүй ч, Бурханы амь хүний дотор орох боломжтой л байдаг. Мянган жилийн хаанчлалын гол ажил нь энэ бөгөөд хэрвээ чи энэ ажлыг ойлгож чадахгүй бол сул дорой болж, унана. Чи шалгалт дунд буух бөгөөд бүр хамгийн аймшигтай нь, Сатанд олзлогдох болно. Бурхан үндсэндээ үгээ хэлэхээр газар дээр ирсэн; харьцаж байгаа зүйл чинь Бурханы үг, харж байгаа зүйл чинь Бурханы үг, сонсож байгаа зүйл чинь Бурханы үг, баримталдаг зүйл чинь Бурханы үг, туулдаг зүйл чинь Бурханы үг бөгөөд Бурхан энэ удаа бие махбодтой болж, хүнийг төгс болгохын тулд голчлон үгийг ашигладаг. Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй, ялангуяа өнгөрсөн үед Есүсийн хийсэн ажлыг хийдэггүй. Тэр хоёр бол Бурхан бөгөөд хоёулаа махбодтой боловч, Тэдний үйлчлэл нь өөр билээ. Есүс ирэх үедээ бас Бурханы ажлын нэг хэсгийг хийж, зарим нэг үг хэлсэн, гэхдээ Түүний гүйцэлдүүлсэн гол ажил юу байсан бэ? Түүний гүйцэлдүүлсэн гол ажил бол цовдлогдох байсан билээ. Тэрээр цовдлолын ажлыг гүйцэлдүүлж, бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд нүгэлт махан биеийн дүртэй болсон ба бүх хүн төрөлхтний нүглийн төлөө нүглийн тахил болсон юм. Энэ бол Түүний гүйцэлдүүлсэн гол ажил билээ. Эцэст нь Тэр хожим ирэх хүмүүсийг замчлах загалмайн замыг бэлдэж өгчээ. Есүсийн ирсэн гол зорилго нь золин аврах ажлыг гүйцэлдүүлэх явдал байсан. Тэрээр бүх хүн төрөлхтнийг золин аварч, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг хүнд авчирч, улмаар тэнгэрийн хаанчлалд хүрэх замыг авчирсан. Үүний үр дүнд, хожим ирсэн хүмүүс бүгд: “Бид загалмайн замаар алхаж, загалмайн төлөө өөрсдийгөө золиослох хэрэгтэй” гэцгээсэн. Мэдээж анх Есүс бас өөр бусад ажил хийсэн бөгөөд хүнийг гэмшүүлж, нүглийг нь улайлгахын тулд зарим нэг үг хэлсэн. Гэхдээ л Түүний үйлчлэл нь цовдлол байсан ба замыг номлож өнгөрүүлсэн гурван жил хагасын хугацаа нь хожим тохиох цовдлолд бэлдэхийн төлөө байсан. Есүс хэд хэдэн удаа залбирсан нь ч бас цовдлолын төлөө байсан юм. Түүний туулсан хэвийн хүний амьдрал болон газар дэлхий дээр амьдарсан гучин гурван жил хагасын хугацаа нь үндсэндээ цовдлолын ажлыг гүйцээхийн төлөө, Түүнд энэ ажлыг явуулах хүч өгөхийн төлөө байсан ба үүний үр дүнд Бурхан цовдлолын ажлыг Түүнд даалгасан. Өнөөдөр, бие махбодтой болсон Бурхан ямар ажлыг гүйцэлдүүлэх вэ? Өнөөдөр Бурхан ерөнхийдөө “Үг махбодоор илрэх” ажлыг гүйцэлдүүлж, үг ашиглан хүнийг төгс болгож, үгийн харьцалт, цэвэршүүлэлтийг хүнээр хүлээн авхуулахын тулд бие махбодтой болсон юм. Өөрийнхөө үгээр Тэр чамд хангалт болон амийг хүртээдэг; Түүний үгээс чи ажил болон үйл хэргийг нь хардаг. Бурхан чамайг гэсгээж, цэвэршүүлэхийн тулд үг ашигладаг, иймээс чи хүндрэл бэрхшээл туулж байвал, энэ чинь бас Бурханы үгээс үүдэлтэй. Өнөөдөр, Бурхан баримт бус, үг ашиглан ажлаа явуулдаг. Түүний үг чамд хүрсний дараа л Ариун Сүнс чиний дотор ажиллаж, чамд зовлон шаналал юм уу баяр баясгаланг мэдрүүлж чадна. Бурханы үг л чамайг

бодит байдал руу аваачиж чадах ба Бурханы үг л чамайг төгс болгох чадвартай. Иймээс чи ядаж л үүнийг ойлгох ёстой: Эцсийн өдрүүдэд Бурханы хийдэг ажил нь үндсэндээ хүн бүрийг төгс болгож, хүнийг замчлахад Өөрийн үгийг ашиглах явдал юм. Тэр бүх ажлаа үгээр дамжуулан хийдэг; чамайг гэсгээхдээ Тэр баримт ашигладаггүй. Зарим хүн Бурханыг эсэргүүцэх үе гардаг. Бурхан чиний тав тухыг ихэд алдагдуулахгүй, махан биеийг чинь гэсгээхгүй, бас чи бэрхшээл ч туулахгүй боловч Бурханы үг чам дээр бууж, чамайг цэвэршүүлмэгц энэ нь тэсвэрлэшгүй санагддаг. Тийм биш гэж үү? Үйлчлэл үзүүлэгчдийн цаг үед Бурхан хүнийг ёроолгүй нүхэнд хая гэж хэлсэн. Үнэхээр хүн ёроолгүй нүхэнд орсон гэж үү? Хүнийг цэвэршүүлэхдээ үг ашигласнаар л хүнийг ёроолгүй нүхэнд оруулсан. Тиймээс эцсийн өдрүүдэд Бурхан бие махбодтой болох үедээ бүгдийг гүйцэлдүүлж, бүхнийг ил болгохын тулд үндсэндээ үг ашигладаг. Тэр юу болохыг чи үгээс нь л харж чадна; Тэр бол Бурхан Өөрөө гэдгийг чи үгээс нь л харж чадна. Бие махбодтой болсон Бурхан газар дэлхийд ирэх үедээ үг хэлэхээс өөр ажил хийдэггүй—тиймээс баримт шаардлагагүй; үг л хангалттай юм. Яагаад гэвэл, Тэрээр гол нь энэ ажлыг хийхээр, Өөрийн хүч чадал болон дээдийн дээд байдлыг хүнд үгээрээ үзүүлж, Өөрийгөө хэрхэн даруухнаар нууж байдгаа хүнд үгээрээ харуулж, мөн Өөрийг нь бүрэн дүүрэн мэдэх боломжийг хүнд үгээрээ олгохын тулд ирсэн. Түүнд юу байгаа, Тэр юу болох нь бүгд Түүний үгэнд бий. Түүний мэргэн ухаан, гайхалтай байдал нь Түүний үгэнд оршдог. Эндээс Бурханы үгээ хэлдэг олон арга барил чамд харагддаг. Энэ бүх хугацаанд Бурханы ажлын дийлэнх нь хүнд чиглэсэн хангалт, илчлэл, харьцалт байсан. Бурхан хүнийг амархан хараагаад байдаггүй, хараасан ч гэсэн үүнийгээ үгээр дамжуулан үйлддэг. Иймээс, Бурхан махбод болсон энэ эрин үед, Бурхан өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөж байгааг дахин үзэх гэж бүү хичээ, үргэлж тэмдэг хүлээхээ боль—энэ нь ямар ч хэрэггүй! Тэдгээр тэмдэг хүнийг төгс болгож чадахгүй! Ний нуугүй хэлэхэд: Өнөөдөр махбод дахь бодитой Бурхан Өөрөө үг л хэлдэг болохоос үйлддэггүй. Энэ бол үнэн! Тэрээр үг ашиглан чамайг төгс болгож, үг ашиглан чамайг хооллож, ундалдаг. Тэр бас үг ашиглан ажилладаг ба Өөрийнхөө бодит байдлыг чамд мэдүүлэхийн тулд баримтын оронд үг ашигладаг. Хэрвээ чи Бурханы ийм төрлийн ажлыг ухамсарлах чадвартай бол амархан сөрөг болохгүй. Та нар сөрөг зүйлд анхаарал хандуулахын оронд эерэг зүйлд л анхаарах ёстой—өөрөөр хэлбэл, Бурханы үг биелсэн ч бай үгүй ч бай, баримт гарч ирсэн ч бай үгүй ч бай, Бурхан хүнийг Өөрийнхөө үгээс амь олж авахад хүргэдэг нь хамгийн агуу тэмдэг төдийгүй маргашгүй баримт юм. Энэ нь Бурханы тухай мэдлэг олж авах хамгийн сайн нотолгоо бөгөөд тэмдгээс агуу тэмдэг юм. Зөвхөн эдгээр үг л хүнийг төгс болгож чадна.

Хаанчлалын эрин үе эхэлмэгц Бурхан үгээ хэлж эхэлсэн. Ирээдүйд эдгээр үг бага багаар биелэх болно, тэр үе нь мөн хүмүүсийн амь өсөж төлөвших үе байх болно. Бурхан хүний ялзарсан зан чанарыг илчлэхдээ үг ашиглах нь илүү бодит, бас илүү чухал бөгөөд хүний итгэлийг төгс болгох ажлаа хийхийн тулд Бурхан

гагцхүү үг ашигладаг, учир нь өнөөдөр бол Үгийн эрин үе бөгөөд энэ эрин хүнээс итгэл, шийдэмгий байдал болон хамтын ажиллагааг шаарддаг. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурханы ажил нь үгээ ашиглан хүнд үйлчилж, хүнийг хангах явдал юм. Бие махбодтой болсон Бурхан үгээ хэлж дууссаны дараа л тэдгээр нь биелж эхлэх болно. Түүнийг үг хэлж байх үед үг нь биелдэггүй, учир нь Түүнийг махбодын үе шатанд байхад үг нь биелэх боломжгүй. Ингэснээр Бурхан бол Сүнс биш, махбод гэдгийг хүн харж, Бурханы бодит байдлыг нүдээрээ үзэх болно. Түүний ажил дууссан өдөр, газар дэлхий дээр хэлэх ёстой бүх үгээ хэлсэн үед нь Түүний үг биелж эхэлнэ. Тэр үгээ хэлж дуусаагүй тул одоо Бурханы үгийн биелэлтийн эрин үе биш юм. Иймээс Бурхан газар дэлхий дээр үгээ хэлсээр байгааг харах үедээ чи Түүний үг биелэхийг бүү хүлээ; Бурхан үг хэлэхээ больж, газар дэлхий дээрх ажлаа дуусгах үе нь Түүний хэлсэн үг биелж эхлэх цаг үе байх болно. Түүний газар дэлхий дээр хэлсэн үгс дотор нэг талаар амийн хангалт, нөгөө талаар болох зүйлс, хийгдэх зүйлс болон хараахан биелээгүй байгаа зүйлсийн тухай зөгнөл агуулагддаг. Есүсийн үгэнд ч бас зөгнөл байсан. Нэг талаар Тэр амиар хангаж, нөгөөтээгүүр зөгнөл хэлсэн юм. Хүмүүсийн нүдээрээ харж чадах зүйлс болон Бурханы хийдэг зүйлс хоорондоо асар их ялгаатай учраас өнөөдөр үг болон баримтыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх тухай огт ярьдаггүй. Бурханы ажил дууссаны дараа л Түүний үг биелэх ба үгийн араас баримт гарч ирэх болно. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан газар дээр үгийн үйлчлэлийг гүйцэтгэдэг ба үгийн үйлчлэлийг гүйцэтгэхдээ зөвхөн үг хэлж, харин өөр хэрэг явдлыг хайхардаггүй. Бурханы ажил өөрчлөгдмөгц Түүний үг биелж эхэлнэ. Өнөөдөр үгийг эхлээд чамайг төгс болгоход ашигладаг; Тэр бүхий л орчлон ертөнцөд алдар суутай болох үед Түүний ажил бүрэн төгс болж, хэлэх ёстой бүх үг хэлэгдэж, бүх үг баримт болсон байх болно. Өөрийнх нь үгээс хүн Түүнийг мэдэж, Тэр юу болохыг, Түүний мэргэн ухаан болон бүх гайхалтай үйл хэргийг хараг гэсэндээ Бурхан эцсийн өдрүүдэд үгийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээр газар дээр ирсэн юм. Хаанчлалын эрин үед Бурхан үндсэндээ үгээрээ бүх хүнийг байлдан дагуулдаг. Ирээдүйд Түүний үг бүх шашин, бүлэглэл, үндэстэн, урсгалд бас хүрнэ. Бурхан байлдан дагуулахын тулд, мөн үг нь хүч, эрх мэдлийг агуулдаг гэдгийг бүх хүнд харуулахын тулд үг ашигладаг—иймээс өнөөдөр та нар зөвхөн Бурханы үгтэй нүүр тулдаг.

Энэ эрин үед Бурханы хэлсэн үг нь Хуулийн эрин үед хэлсэн үгээс өөр, мөн Нигүүлслийн эрин үед хэлсэн үгээс ч ялгаатай байдаг. Нигүүлслийн эрин үед Бурхан үгийн ажил хийгээгүй, харин бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд ердөө цовдлолыг л үзүүлсэн. Библид зөвхөн, Есүс яагаад цовдлогдох болсныг, загалмай дээр байхдаа Түүний мэдэрсэн зовлонг болон хүн Бурханы төлөө хэрхэн цовдлогдох ёстой тухай л дурдсан байдаг. Тэрхүү эрин үед Бурханы хийсэн бүх ажил цовдлол дээр төвлөрч байсан. Хаанчлалын эрин үед бие махбодтой болсон Бурхан үгээрээ Өөрт нь итгэдэг бүх хүнийг байлдан дагуулдаг. Энэ нь “Үг нь махбодоор илэрсэн” хэрэг юм; Бурхан эцсийн өдрүүдэд энэ ажлыг хийхээр ирсэн,

өөрөөр хэлбэл, “Үг нь махбодоор илэрсэн” бодит ач холбогдлыг биелүүлэхээр ирсэн юм. Тэр зөвхөн үг хэлдэг ба баримт гарч ирэх нь ховор байдаг. Үг нь махбодоор илрэхийн мөн чанар яг энэ бөгөөд бие махбодтой болсон Бурхан үгээ хэлэх үе бол Үг нь махбодоор илэрч, Үг нь махбодод ирж байгаа хэрэг юм. “Анх Үг байв, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байлаа, тэгээд Үг нь махбод болсон юм.” Энэ (Үг нь махбодоор илрэх ажил) нь эцсийн өдрүүдэд Бурханы гүйцэтгэх ажил бөгөөд Түүний бүхий л удирдлагын төлөвлөгөөний сүүлчийн бүлэг юм, иймээс Бурхан газар дээр ирж, үгээ махбодоор илэрхийлэх ёстой. Өнөөдөр хийдэг зүйл, хожим хийх зүйл, Бурханы гүйцэлдүүлэх зүйл, хүний эцсийн хүрэх газар, аврагдах хүмүүс, устгагдах хүмүүс гэх мэт эцэст нь биелэх ёстой энэ бүх ажлыг бүгдийг нь тодорхой өгүүлсэн ба бүгд Үг нь махбодоор илрэхийн бодит ач холбогдлыг биелүүлэхийн төлөө байдаг. Өмнө нь тунхагласан захиргааны зарлиг болон хууль, устгагдах хүмүүс, амралтад орох хүмүүс зэрэг эдгээр үг бүгд биелэх ёстой. Энэ бол эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурханы голлон биелүүлдэг ажил юм. Бурханы урьдчилан тогтоосон хүмүүс хаана харьяалагдах болон Бурханы урьдчилан тогтоогоогүй хүмүүс хаана харьяалагдахыг, Түүний ардууд болон хөвгүүд хэрхэн ангилагдахыг, Израильд юу тохиолдохыг, Египетэд юу тохиолдохыг Тэрээр хүмүүст ойлгуулдаг бөгөөд ирээдүйд эдгээр үг нэг бүрчлэн биелнэ. Бурханы ажлын алхмууд эрчээ авч байна. Эрин үе бүрд хийгдэх зүйлийг, бие махбодтой болсон Бурханы эцсийн өдрүүдэд хийх зүйлийг болон Түүний биелүүлэх гэж байгаа үйлчлэлийг хүнд илчлэхдээ Бурхан үгийн арга барилыг ашигладаг бөгөөд эдгээр үг нь бүгд Үг нь махбодоор илрэхийн бодит ач холбогдлыг биелүүлэхийн тулд байдаг.

“Бурханы тэмдэг, гайхамшгийг харахад анхаарлаа төвлөрүүлдэг бүх хүн хаягдана; тэд төгс болгуулах хүмүүс биш” гэж Би өмнө нь хэлж байсан. Би маш олон үг хэлсэн атал хүн энэ ажлын талаар өчүүхэн төдий ч мэдлэггүй байдаг бөгөөд энэ хүртэл ирчхээд бас л тэмдэг гайхамшиг гуйсаар байдаг. Бурханд итгэх итгэл чинь тэмдэг, гайхамшгийн эрэл хайгуул төдийхөн зүйл үү, эсвэл энэ нь амь олж авахын төлөө байдаг уу? Тухайн үед Есүс ч бас олон үг хэлсэн бөгөөд зарим нь хараахан биелээгүй байгаа. Есүс бол Бурхан биш гэж чи хэлж чадах уу? Тэр бол Христ бөгөөд Бурханы хайртай Хүү гэдгийг Бурхан гэрчилсэн. Чи үүнийг үгүйсгэж чадах уу? Өнөөдөр, Бурхан зөвхөн үг хэлдэг тул хэрвээ чи үгийг нь нэгд нэггүй мэдэж чадахгүй бол бат зогсож чадахгүй. Чи Түүнийг Бурхан болохоор нь Түүнд итгэдэг юм уу, эсвэл үг нь биелдэг эсэхээс нь хамаарч Түүнд итгэдэг юм уу? Чи тэмдэг гайхамшигт итгэдэг үү, эсвэл Бурханд итгэдэг үү? Өнөөдөр Тэр тэмдэг гайхамшиг үзүүлдэггүй—Тэр үнэхээр Бурхан мөн үү? Хэлсэн үг нь биелдэггүй бол Тэр үнэхээр Бурхан мөн үү? Хэлсэн үг нь биелдэг эсэхээр Бурханы мөн чанар тодорхойлогддог уу? Яагаад зарим хүн дандаа л Бурханы үг биелсний дараа Түүнд итгэнэ гэж хүлээж суудаг вэ? Энэ нь, тэд Түүнийг мэддэггүй гэсэн үг биш үү? Ийм үзэлтэй хүмүүс бүгд Бурханыг үгүйсгэдэг хүмүүс юм. Тэд Бурханыг хэмжихдээ үзэл

ашигладаг; үг нь биелдэг бол Бурханд итгэж, биелдэггүй бол итгэдэггүй; тэд үргэлж тэмдэг, гайхамшгийг эрэлхийлдэг. Тэд орчин үеийн фарисайчууд биш гэж үү? Чиний бат зогсож чадах эсэх нь бодитой Бурханыг мэддэг эсэхээс чинь хамаардаг—энэ бол амин чухал! Чамд Бурханы үгийн бодит байдал хэдий чинээ их байна, Бурханы бодит байдлын тухай мэдлэг чинь төдий чинээ их байдаг бөгөөд шалгалтуудын үеэр чи илүү бат зогсож чаддаг. Чи тэмдэг, гайхамшиг харахад хэдий чинээ их анхаарна, төдий чинээ бат зогсож чадахгүй бөгөөд шалгалтын дунд унах болно. Тэмдэг, гайхамшиг бол суурь биш; Бурханы бодит байдал л амь мөн. Бурханы ажлаас гарах үр нөлөөг зарим хүн мэддэггүй. Тэд Бурханы ажлын тухай мэдлэгийг эрэлхийлэлгүй, будилаан дунд өдөр хоногоо өнгөрүүлдэг. Тэдний эрэл хайгуул нь үргэлж Бурханаар хүслээ хангуулах л зорилготой байдаг бөгөөд үүний дараа л нухацтайгаар итгэдэг. Бурханы үг биелсэн үед л амийг эрэлхийлнэ, харин биелэхгүй бол тэдний хувьд амийг эрэлхийлэх ямар ч боломжгүй гэж тэд хэлдэг. Бурханд итгэх итгэл нь тэмдэг, гайхамшгийг харах эрэл хайгуул, мөн тэнгэр лүү болон гуравдагч тэнгэр өөд гарах эрэл хайгуул гэж хүн боддог. Бурханд итгэх итгэл нь бодит байдалд орох эрэл хайгуул, амийн эрэл хайгуул, мөн Бурханаар авхуулах эрэл хайгуул гэж хэлэх хэн ч байхгүй. Ийм эрэл хайгуулд ямар үнэ цэн байх юм бэ? Бурханы тухай мэдлэгийг, мөн Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг эрэлхийлдэггүй хүмүүс бол Бурханд итгэдэггүй хүмүүс бөгөөд тэд бол Бурханыг доромжлогчид юм!

Одоо Бурханд итгэх итгэл гэж юу болохыг та нар ойлгож байна уу? Бурханд итгэнэ гэдэг нь тэмдэг, гайхамшгийг харах явдал уу? Энэ нь тэнгэр өөд гарах явдал уу? Бурханд итгэх огтхон ч амаргүй. Тэдгээр шашны итгэлийг үгүй хийх ёстой; өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулахаар эрэлхийлэх, тэмдэг, гайхамшиг дээр төвлөрөх, Бурханы нигүүлсэл, амар амгалан, баяр хөөрт илүү их шунах, махан биеийн хэтийн ирээдүй, тав тухыг эрэлхийлэх зэрэг нь шашны хэрэгжүүлэлт бөгөөд шашны ийм хэрэгжүүлэлт нь тодорхойгүй төрлийн итгэл байдаг. Өнөөдөр Бурханд итгэх бодитой итгэл гэж юу вэ? Энэ бол Бурханы үгийг амь-бодит байдлаа болгон хүлээж авах, мөн Бурханы үгээс Түүнийг мэдэж, Түүнийг жинхэнээсээ хайрлах юм. Тодруулбал: Энэ нь, Бурханыг дуулгавартай дагаж, Бурханыг хайрлаж, Бурханы бүтээлийн биелүүлэх ёстой үүргийг гүйцэтгэхийн төлөө Бурханд итгэх итгэл юм. Энэ бол Бурханд итгэхийн зорилго билээ. Та нар, Бурханы хайр татам байдлын тухай, Бурхан хэр хүндлүүлэх үнэ цэнтэй тухай, Бурхан бүтээлүүддээ хэрхэн авралын ажил хийж, тэднийг төгс болгодог тухай мэдлэгийг олж авах ёстой—энэ бол Бурханд итгэхдээ эзэмших ёстой наад захын зүйл юм. Бурханд итгэх итгэл нь үндсэндээ махан биеийн амьдралаа Бурханыг хайрлах амьдрал болгон өөрчилж, завхрал доторх амьдралаа Бурханы үгийн амь доторх амьдрал болгон өөрчилж, Сатаны эзэмшлээс гарч, Бурханы халамж, хамгаалалт дор амьдрахын нэр юм. Энэ бол, махан биедээ бус, Бурханд дуулгавартай байж чадах явдал, бүхий л зүрх сэтгэлийг чинь олж авч, чамайг төгс болгох боломжийг Бурханд олгож, ялзарсан

сатанлаг зан чанараас өөрийгөө чөлөөлөх явдал юм. Бурханд итгэх итгэл нь үндсэндээ Бурханы агуу хүч чадал, алдар сууг чам дээр илэрхийлэхийн төлөө, мөн чамайг Бурханы хүслийг биелүүлж, Бурханы төлөвлөгөөг гүйцэлдүүлж, Сатаны өмнө Бурханд гэрчлэл хийж чаддаг байлгахын төлөө байдаг. Бурханд итгэх итгэл нь тэмдэг гайхамшиг харах хүсэлд л төвлөрсөн зүйл байж болохгүй, өөрийн махан биеийн төлөө ч байх ёсгүй. Бурханыг мэдэх эрэл хайгуулын төлөө, Бурханд дуулгавартай байж, Петр шиг үхэн үхтлээ Бурханыг дуулгавартай дагахын төлөө Бурханд итгэх ёстой. Эдгээр нь Бурханд итгэхийн гол зорилт юм. Хүн Бурханыг мэдэж, Бурханыг сэтгэл хангалуун болгохын тулд Бурханы үгийг идэж уудаг. Бурханы үгийг идэж, уух нь чамд Бурханы тухай илүү их мэдлэг өгдөг, үүний дараа л чи Бурханд дуулгавартай байж чадна. Бурханы талаар мэдлэгтэй байж л чи Бурханыг хайрлаж чадна, энэ бол хүний Бурханд итгэх итгэлд байх ёстой зорилго юм. Бурханд итгэхдээ чи үргэлж тэмдэг, гайхамшиг харахаар оролддог бол Бурханд итгэх энэ үзэл санаа чинь буруу байна. Бурханд итгэх нь үндсэндээ Бурханы үгийг амь-бодит байдал болгон хүлээн авах явдал юм. Бурханы амнаас гарсан үгийг хэрэгжүүлж, тэдгээрийг өөрсдийнхөө дотор биелүүлэх нь л Бурханы зорилгын биелэлт билээ. Бурханд итгэхдээ хүн Бурханаар төгс болгуулж, Бурханд захирагдаж, Бурханд бүрэн дуулгавартай байхаар мэрийх хэрэгтэй. Хэрвээ чи гомдолгүйгээр Бурханд дуулгавартай байж, Бурханы хүслийг анхаарч, Петрийн биеийн хэмжээнд хүрч, Бурханы хэлсэн Петрийн хэв маягийг эзэмшиж чадвал Бурханд итгэх итгэлдээ амжилт олсон байх бөгөөд Бурханаар авхуулсныг чинь энэ нь илтгэнэ.

Бурхан ажлаа бүхий л орчлон ертөнц даяар хийдэг. Түүнд итгэдэг бүх хүн Түүний үгийг хүлээн авч, Түүний үгийг идэж уух ёстой; Бурханы үзүүлдэг тэмдэг, гайхамшгийг харлаа гээд Бурханаар авхуулж чадах хүн нэг ч байхгүй. Эрин үеүдийн туршид хүнийг төгс болгохын тулд Бурхан үргэлж үг ашиглаж ирсэн. Тиймээс та нар хамаг анхаарлаа тэмдэг, гайхамшигт хандуулах ёсгүй, харин Бурханаар төгс болгуулахаар мэрийх ёстой. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед Бурхан зарим нэг үг хэлсэн ба Нигүүлслийн эрин үед Есүс ч бас олон үг хэлсэн. Есүсийг олон үг хэлсний дараа хожмын элч, шавь нар нь хүмүүсийг Есүсийн гаргасан тушаалуудын дагуу хэрэгжүүлж, Есүсийн хэлсэн үг, зарчмын дагуу туршлагажихад залж чиглүүлсэн юм. Эцсийн өдрүүдэд, хүнийг төгс болгохын тулд Бурхан үндсэндээ үг ашигладаг. Тэр хүнийг дарангуйлах юм уу үнэмшүүлэхийн тулд тэмдэг, гайхамшиг ашигладаггүй; Бурханы хүч чадлыг энэ нь ил болгож чадахгүй. Бурхан зөвхөн тэмдэг, гайхамшиг үзүүлсэн бол Бурханы бодит байдлыг илэрхий болгох боломжгүй болж, улмаар хүнийг төгс болгох ч боломжгүй байх байв. Бурхан тэмдэг, гайхамшгаар хүнийг төгс болгодоггүй, харин үгээр хүнийг усалж, хариулдаг бөгөөд үүний дараа л хүн бүрэн дуулгавартай болж, Бурханы талаар мэдлэгтэй болдог. Энэ бол Түүний хийдэг ажил, хэлдэг үгийн зорилго юм. Бурхан хүнийг төгс болгохын тулд тэмдэг, гайхамшиг үзүүлэх арга барил

ашигладаггүй—Тэрээр хүнийг төгс болгохын тулд үг ашигладаг ба ажлын олон өөр арга барилыг ашиглаж хүнийг төгс болгодог. Үгийн цэвэршүүлэлт, харьцалт, засалт, хангалтын аль нь байх нь хамаагүй, Бурхан хүнийг төгс болгож, Бурханы ажил, мэргэн ухаан, гайхалтай байдлын талаар хүнд илүү их мэдлэг өгөхийн тулд олон өөр өнцгөөс ярьдаг. Бурхан эцсийн өдрүүдэд эрин үеийг төгсгөх цагт хүн бүрэн төгс болгуулсныхаа дараа тэмдэг, гайхамшгийг харах шаардлагыг хангана. Бурханыг мэдэж авч, Бурханыг юу ч хийсэн бай, дуулгавартай дагаж чаддаг байх үедээ чи тэмдэг, гайхамшгийг харсан ч Бурханы талаар ямар нэг үзэл тээхээ болино. Одоогоор чи ялзарсан, Бурханд бүрэн дуулгавартай байх чадваргүй, ийм байдалтай байж чи өөрийгөө тэмдэг, гайхамшиг харах эрхтэй гэж бодоо юу? Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлдэг үе нь Бурхан хүнийг шийтгэх үе, эрин үе солигдох үе, түүнчлэн эрин үе дуусах үе байдаг. Бурхан ажлаа хэвийн явуулж байх үедээ тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй. Тэмдэг, гайхамшиг үзүүлэх нь инээд хүрэм амархан боловч энэ нь Бурханы ажлын зарчим биш, мөн Бурхан хүнийг удирдахын зорилго ч биш. Хэрвээ хүн тэмдэг, гайхамшиг харсан бол, хэрвээ Бурханы сүнслэг бие хүнд харагдсан бол бүх хүн Бурханд итгэхгүй гэж үү? Асар их гай гамшиг дундаас гарч ирдэг бүлэг ялагчдыг Зүүн зүгээс олж авдаг гэдгийг Би өмнө нь хэлсэн. Эдгээр үг ямар утга учиртай вэ? Авхуулсан энэ хүмүүс шүүлт, гэсгээлт, харьцалт, засалт болон бүх төрлийн цэвэршүүлэлтийг туулсны дараа л үнэхээр дуулгавартай болсон гэсэн үг юм. Ийм хүмүүсийн итгэл нь тодорхойгүй, хийсвэр бус, харин бодитой байдаг. Тэд ямар ч тэмдэг, гайхамшиг, ямар ч ер бусын зүйл хараагүй; тэд ойлгоход бэрх бичиг үсэг, хоосон номлол, гүн гүнзгий ойлголтын тухай ярьдаггүй; харин тэдэнд бодит байдал, Бурханы үг болон Бурханы бодит байдлын тухай жинхэнэ мэдлэг байдаг. Ийм бүлэг хүмүүс Бурханы хүч чадлыг илэрхий болгож илүү сайн чадах бус уу? Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил нь бодитой ажил юм. Өөрийнхөө эрин үед Есүс хүнийг төгс болгох гэж бус, харин золин аврах гэж ирсэн, иймээс хүмүүсээр Өөрийгөө дагуулахын тулд зарим нэг ер бусын зүйл үзүүлсэн. Учир нь Тэр гол нь цовдлолын ажлыг гүйцэтгэхээр ирсэн ба тэмдэг үзүүлэх нь Түүний үйлчлэлийн хүрээн дэх ажил биш байсан юм. Тэр тэмдэг, гайхамшгууд нь Түүний ажлыг илүү үр нөлөөтэй болгохын тулд хийгдсэн; тэдгээр нь нэмэлт ажил байсан ба бүхий л эрин үеийн ажлыг төлөөлж байгаагүй юм. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед Бурхан бас зарим нэг тэмдэг, гайхамшиг үзүүлсэн—гэхдээ Бурханы өнөөдөр хийдэг ажил нь бодитой ажил бөгөөд Тэр одоо тэмдэг, гайхамшиг үзүүлэхгүй нь лавтай. Түүнийг тэмдэг, гайхамшиг үзүүлбэл бодитой ажил нь эмх замбараагаа алдаж, Тэрээр ажлаа цааш хийх боломжгүй болох байсан. Бурхан үг ашиглан хүнийг төгс болгоно гэж хэлчхээд мөн л тэмдэг, гайхамшиг үзүүлсэн бол хүн Түүнд үнэхээр итгэдэг эсэх нь илэрхий болж чадах байсан уу? Иймээс Бурхан тиймэрхүү зүйл хийдэггүй. Хүний дотор хэтэрхий их шашны зүйл бий; Бурхан, хүний доторх шашны бүх үзэл болон ер бусын зүйлсийг хөөн зайлуулж, Бурханы бодитой байдлыг хүнд мэдэгдэхийн тулд эцсийн өдрүүдэд

ирсэн. Тэрээр хийсвэр, бодит бус Бурханы дүрийг, өөрөөр хэлбэл, ерөөсөө оршин байдаггүй Бурханы дүрийг арилгахаар ирсэн юм. Иймээс одоо цорын ганц эрхэм чухал зүйл бол чи бодит байдлын тухай мэдлэгтэй байх явдал! Үнэн бүхнийг дийлдэг. Чамд өнөөдөр хэр их үнэн байна вэ? Тэмдэг, гайхамшиг үзүүлдэг бүхэн Бурхан мөн үү? Муу ёрын сүнснүүд ч бас тэмдэг гайхамшиг үзүүлж чадна; тэд бүгд Бурхан мөн үү? Бурханд итгэхдээ хүний эрж хайдаг зүйл нь үнэн, эрэлхийлдэг зүйл нь амь болохоос тэмдэг, гайхамшиг биш билээ. Бүх хүний Бурханд итгэх зорилго ийм байх ёстой.

БУРХАНЫ БОДИТ БАЙДАЛД ТУЙЛЫН ДУУЛГАВАРТАЙ БАЙЖ ЧАДДАГ ХҮМҮҮС БОЛ БУРХАНЫГ ҮНЭХЭЭР ХАЙРЛАДАГ ХҮМҮҮС ЮМ

Бодит байдлын тухай мэдлэгтэй болох, Бурханы ажлыг нэгд нэггүй ойлгох—энэ хоёр нь Түүний үгээс харагддаг бөгөөд эдгээр айлдвараар л дамжуулан чи гэгээрэл олж авч чадна. Тиймээс чи Бурханы үгээр илүү их зэвсэглэх ёстой. Бурханы үгийн талаарх ойлголтоо нөхөрлөлөөр ярилц, ийм маягаар чи бусдыг гэгээрүүлж, тэдэнд гарах гарц өгч чадна—энэ бол бодитой зам юм. Бурхан чамд зориулж орчныг зохицуулахаас өмнө та нар дор бүрнээ Түүний үгээр зэвсэглэх ёстой. Энэ бол хүн бүрийн хийх ёстой зүйл; хойшлуулшгүй эн тэргүүний зүйл мөн. Эхлээд, Бурханы үгийг хэрхэн ууж, идэхээ мэддэг байх хэмжээнд хүр. Хийж чаддаггүй зүйлсийнхээ хувьд Түүний үгээс хэрэгжүүлэлтийн замыг эрж хайж, ойлгодоггүй аливаа асуудал, эсвэл өөрт чинь байж болох аливаа бэрхшээлийг эдгээр айлдвараас хай. Бурханы үгийг өөрийн хангалт болгож, бодит бэрхшээл болон асуудлаа шийдвэрлэхэд чинь туслах боломжийг тэдгээрт олго; бас Түүний үгийг амьдралынхаа туслагч болго. Эдгээр зүйл хичээл чармайлт гаргахыг чамаас шаарддаг. Бурханы үгийг идэж, уухдаа үр дүнд хүрэх ёстой; чи Түүний өмнө зүрх сэтгэлээ тайван байлгаж чаддаг байх ёстой, ямар нэг асуудалтай тулгарах болгондоо Түүний айлдваруудын дагуу хэрэгжүүлэх ёстой. Асуудалтай тулгараагүй байх үедээ чи зүгээр л Бурханы үгийг идэж, уухад анхаарах учиртай. Заримдаа чи залбирч, Бурханы хайрыг тунгаан бодож, Бурханы үгийн талаарх ойлголтоо нөхөрлөж, дотроо мэдэрсэн гэгээрэл, гэрэлтүүлэлт болон эдгээр айлдварыг унших үедээ гаргасан хариу үйлдлийнхээ талаар ярилцаж болох юм. Түүнчлэн, чи хүмүүст гарах гарц өгч чадна. Зөвхөн энэ л бодитой. Үүнийг хийхийн зорилго нь Бурханы үгийг өөрийн бодитой хангалт болгох явдал билээ.

Нэг өдрийн хугацаанд хэдэн цагийг чи үнэхээр Бурханы өмнө өнгөрүүлдэг вэ? Өдөр хоногийнхоо хэр ихийг Бурханд үнэхээр өгдөг вэ? Хэр ихийг махан биед өгдөг вэ? Зүрх сэтгэлээ үргэлж Бурхан руу хандуулж байх нь Бурханаар төгс болгуулах

зөв зам дээр байх эхний алхам юм. Чи зүрх сэтгэл, бие болон бүхий л жинхэнэ хайраа Бурханд зориулж, тэдгээрийг Түүний өмнө тавиад, Түүнд бүрэн дуулгавартай байж, махан бие, гэр бүл, өөрийнхөө хувийн хүслийн төлөө биш, харин Бурханы гэрийн ашиг сонирхлын төлөө Түүний хүсэлд туйлын хайхрамжтай байж, бүх зүйл дээр Бурханы үгийг зарчим, суурь болгон авч үзэж чаддаг бол ийн үйлдсэнээр санаа зорилго, үзэл бодол чинь бүгд зөв байх бөгөөд чи Бурханы өмнө магтаалыг нь хүртдэг хүн байх болно. Бурханы дуртай хүмүүс бол Түүнд туйлын ханддаг хүмүүс юм; тэд бол ганцхан Түүнд үнэнч байж чаддаг хүмүүс билээ. Бурханы үзэн яддаг хүмүүс бол Түүнд хайхрамжгүй ханддаг, Түүний эсрэг тэрсэлдэг хүмүүс юм. Түүнд итгэдэг, Түүнийг үргэлж таашаахыг хүсдэг мөртөө өөрсдийгөө Түүний төлөө бүрэн зарлагадаж чаддаггүй хүмүүсийг Тэр үзэн яддаг. Түүнд хайртай гэж хэлдэг боловч зүрх сэтгэлдээ Түүний эсрэг тэрсэлдэг хүмүүсийг Тэр үзэн яддаг; хууран мэхлэхийн тулд цэцэг цэлмэг, чихэнд чимэгтэй үг ашигладаг хүмүүсийг Тэр үзэн яддаг. Бурханд үнэхээр зориулдаггүй, эсвэл Түүний өмнө үнэхээр захирагдаагүй хүмүүс урвамтгай бөгөөд уг чанартаа хэтэрхий биеэ тоосон байдаг. Хэвийн агаад бодитой Бурханы өмнө чин сэтгэлээсээ дуулгавартай байж чаддаггүй хүмүүс бол бүр ч их биеэ тоосон байдаг бөгөөд тэд ялангуяа тэргүүн тэнгэрэлчийн ачлалт үр удам юм. Өөрсдийгөө Бурханы төлөө үнэхээр зарлагаддаг хүмүүс бүхий л оршихуйгаа Түүнд зориулж, өөрсдийгөө Түүний өмнө тавьдаг; тэд Түүний бүх үг, ажилд чин сэтгэлээсээ захирагдаж чаддаг ба Түүний үгийг хэрэгжүүлж чаддаг. Тэд Бурханы үгийг хүлээн авч, оршин тогтнолынхоо суурь болгож чаддаг бөгөөд Бурханы үгэн дотроос аль хэсгийг нь хэрэгжүүлэхээ олж мэдэхийн тулд чин сэтгэлээсээ хайж чаддаг. Тэд бол үнэхээр Бурханы өмнө амьдардаг хүмүүс юм. Чи ийм маягаар хэрэгжүүлэх юм бол энэ нь аминд чинь ашиг тустай байх бөгөөд Бурханы үгийг идэж, ууснаар өөрийнхөө дотоод хэрэгцээ, дутагдлыг хангаж, улмаар амь зан чанар чинь өөрчлөгдвөл энэ нь Бурханы хүслийг хангалуун байлгана. Хэрвээ чи Бурханы шаардлагын дагуу үйлддэг бол, мөн махан биеийг хангахын оронд Түүний хүслийг хангалуун байлгадаг бол үүгээрээ Бурханы үгийн бодит байдалд орсон байх болно. Бурханы үгийн бодит байдалд орох гэдэг нь чи үүргээ биелүүлж, Бурханы ажлын шаардлагыг хангаж чадна гэсэн үг юм. Иймэрхүү бодитой үйлдлүүдийг л Түүний үгийн бодит байдалд орох гэж нэрлэж болно. Хэрвээ чи энэ бодит байдалд орж чаддаг бол чамд үнэн байна. Энэ нь бодит байдалд орохын эхлэл юм; чи эхлээд энэ сургуулилтыг хийх ёстой ба тэр үед л бүр илүү гүн гүнзгий бодит байдалд орж чадна. Тушаалуудыг хэрхэн мөрдөх, Бурханы өмнө хэрхэн үнэнч байх талаар бод; хэзээ хаанчлалд орж чадах талаараа байнга бүү бод. Зан чанар чинь өөрчлөгдөхгүй бол боддог юм чинь хэрэггүй байх болно! Бурханы үгийн бодит байдалд орохын тулд чи эхлээд өөрийн санаа бодлыг бүгдийг нь Бурханы төлөө болгох ёстой—энэ бол хамгийн наад захын шаардлага юм.

Одоогоор олон хүн шалгалтуудын дунд байгаа ба тэд Бурханы ажлыг ойлгодоггүй. Гэхдээ Би чамд хэлье: Хэрвээ чи үүнийг ойлгохгүй бол энэ талаар

шүүлт хийхгүй байсан чинь дээр. Магадгүй үнэн бүхэлдээ ил болох өдөр ирэх бөгөөд тэр үед чи ойлгоно. Шүүлт хийхгүй байх нь чамд тустай ч чи зүгээр л идэвхгүйгээр хүлээж болохгүй. Чи идэвхтэйгээр орохын тулд эрж хайх ёстой; тэр үед л чи үнэхээр ордог хүн байх болно. Тэрслүү байдлынхаа улмаас хүмүүс үргэлж бодитой Бурханы талаар үзэл бий болгож байдаг. Иймээс бүх хүн дуулгавартай байж сурах шаардлагатай, учир нь бодитой Бурхан бол хүн төрөлхтний хувьд үлэмж их шалгалт билээ. Хэрвээ чи бат зогсож чадахгүй бол бүх зүйл дуусна; бодитой Бурханы бодит байдлын талаар ойлгодоггүй бол чи Бурханаар төгс болгуулж чадахгүй. Хүмүүс төгс болгуулж чадах эсэхийг шийдвэрлэх чухал алхам нь Бурханы бодит байдлын тухай ойлгох явдал юм. Бие махбодтой болсон Бурхан газар дээр ирсэн бодит байдал нь хүн нэг бүрийн хувьд шалгалт мөн; хэрвээ чи энэ тал дээр бат зогсож чаддаг бол Бурханыг мэддэг, Түүнийг үнэхээр хайрладаг хүн байна. Хэрвээ чи энэ тал дээр бат зогсож чаддаггүй бол, мөн Сүнсэнд л итгээд, Бурханы бодит байдалд итгэж чаддаггүй бол Бурханд итгэх итгэл чинь хэчнээн их байлаа ч, энэ нь нэмэргүй. Хэрвээ чи нүдэнд үзэгдэх Бурханд итгэж чаддаггүй бол Бурханы Сүнсэнд итгэж чадна гэж үү? Чи ердөө Бурханыг хуурахаар оролдож байгаа биш гэж үү? Чи нүдэнд үзэгдэж, гарт баригдах Бурханы өмнө дуулгавартай байдаггүй, тэгвэл чи Сүнсний өмнө дуулгавартай байж чадах уу? Сүнс бол үзэгдэж, баригддаггүй, иймд чи Бурханы Сүнсэнд захирагддаг гэж хэлэх үедээ утгагүй юм ярьж байгаа бус уу? Тушаалуудыг мөрдөх гол түлхүүр нь бодитой Бурханы талаар ойлголттой байх явдал юм. Бодитой Бурханы талаар ойлголттой болмогцоо чи тушаалуудыг мөрдөж чадна. Тушаалуудыг мөрдөх нь хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй: Нэг нь Түүний Сүнсний мөн чанарыг хадгалж, Сүнсний өмнө Сүнсний шинжилгээг хүлээн зөвшөөрч чаддаг байх; нөгөө нь Бурханы махбод болсон биеийг үнэхээр ойлгож чаддаг байж, жинхэнэ дуулгавартай байдалд хүрэх. Махан биеийн өмнө ч бай, эсвэл Сүнсний өмнө ч бай, хүн Бурханд захирагдаж, Бурханыг хүндлэх сэтгэлийг үргэлж өвөрлөх ёстой. Зөвхөн ийм хүн л төгс болгуулах эрхтэй. Хэрвээ чамд бодитой Бурханы бодит байдлын талаарх ойлголт байгаа бол—өөрөөр хэлбэл, энэхүү шалгалтад чи бат зогссон бол—чиний хувьд юу ч хэцүү байхгүй.

“Тушаалуудыг мөрдөхөд амархан; чи зүгээр л Бурханы өмнө байхдаа дохиж зангалгүйгээр илэн далангүй, үнэн сэтгэлээсээ ярих хэрэгтэй; энэ нь тушаалуудыг мөрдөж байгаа хэрэг” гэж зарим хүн хэлдэг. Тэр нь зөв үү? Тэгвэл, Бурханы ар хударгаар Түүнийг эсэргүүцэх хэдэн юм хийвэл үүнийг тушаалуудыг мөрдөж байна гэж тооцох уу? Тушаалуудыг мөрдөх гэдэг нь юуг агуулдгийг чи нэгд нэггүй ойлгох ёстой. Энэ нь Бурханы бодит байдлыг үнэхээр ойлгодог уу, үгүй юү гэдэгтэй чинь холбоотой; хэрвээ чи бодит байдлын тухай ойлгодог ба энэхүү шалгалтын үеэр бүдэрч, унадаггүй бол чамайг хүчтэй гэрчлэлтэй гэж тооцож болно. Бурханы төлөө цангинасан гэрчлэл хийх нь чамд бодитой Бурханы талаарх ойлголт байгаа юу, үгүй юү гэдэгтэй болон эгэл жирийн байгаад зогсохгүй хэвийн энэ хүний өмнө дуулгавартай байж, бүр үхэлд хүртэл дуулгавартай байж чадах уу, үгүй юү гэдэгтэй

чинь үндсэндээ хамаатай. Хэрвээ чи энэ дуулгавартай байдлаар дамжуулан Бурханы төлөө үнэхээр гэрчлэл хийдэг бол Бурханаар авхуулсан гэсэн үг юм. Үхэлд хүртэл захирагдаж, Түүний өмнө гомдоллохгүй, шүүлт хийхгүй, гүжирдэхгүй, ямар ч үзэлгүй, ямар нэгэн далд санаагүй байж чаддаг бол ийм маягаар Бурхан алдрыг олж авна. Хүний дорд үздэг эгэл хүний өмнө дуулгавартай байж, ямар ч үзэлгүйгээр үхэлд хүртэл захирагдаж чаддаг байх нь жинхэнэ гэрчлэл билээ. Хүмүүсийг ор гэж Бурханы шаарддаг бодит байдал нь Түүний үгийг дуулгавартай дагаж, хэрэгжүүлж, бодитой Бурханы өмнө бөхийж, завхралаа мэдэж, Түүний өмнө зүрх сэтгэлээ нээж, эцэст нь эдгээр үгээр нь дамжуулан Түүгээр авхуулж чаддаг байх явдал юм. Эдгээр айлдвар чамайг байлдан дагуулж, чамайг Түүнд бүрэн дуулгавартай болгох үед Бурхан алдрыг олж авдаг; үүгээр дамжуулан Тэр Сатаныг шившиглэж, Өөрийн ажлыг дуусгадаг. Бие махбодтой болсон Бурханы бодитой байдлын талаар ямар ч үзэлгүй байх үедээ буюу энэ шалгалтад бат зогсох үедээ чи энэ гэрчлэлийг сайн хийжээ. Хэрвээ чамд бодитой Бурханы талаар бүрэн ойлгож, Петр шиг үхэлд хүртэл захирагдаж чадах өдөр ирвэл чи Бурханаар авхуулж, төгс болгуулна. Бурханы хийдэг, чиний үзэлтэй нийцдэггүй зүйл бол чамд зориулсан шалгалт юм. Хэрвээ Бурханы ажил чиний үзэлтэй нийцэж байсан бол энэ нь чамаас зовохыг, эсвэл цэвэршүүлэгдэхийг шаардахгүй. Түүний ажил маш бодитой, чиний үзэлтэй нийцдэггүй учраас тийм үзлийг хаяхыг чамаас шаарддаг. Ийм учраас энэ нь чиний хувьд шалгалт юм. Бурханы бодит байдлаас л болж бүх хүн шалгалтуудын дунд байгаа; Түүний ажил ер бусын биш, харин бодитой. Түүний бодитой үгсийг, Түүний бодитой айлдваруудыг ямар ч үзэлгүйгээр бүрэн ойлгосноор, мөн ажил нь бодитой болох тусам Түүнийг чин сэтгэлээсээ хайрлаж чаддаг байснаар чи Түүгээр авхуулна. Бурханы олж авах бүлэг хүмүүс бол Бурханыг мэддэг хүмүүс; өөрөөр хэлбэл, Түүний бодит байдлыг мэддэг хүмүүс юм. Үүнээс гадна, тэд бол Бурханы бодитой ажилд захирагдаж чаддаг хүмүүс билээ.

Махбодод байх хугацаандаа Бурханы хүмүүсээс шаарддаг дуулгавартай байдал нь хүмүүсийн төсөөлдөг шиг шүүлт хийхгүй, эсэргүүцэхгүй байх явдал биш; харин ч, Түүний үгийг амьдралын зарчим, оршин тогтнолын сууриа болгон ашиглаж, үгийнх нь мөн чанарыг гарцаагүй хэрэгжүүлж, Түүний хүслийг бүрэн дүүрэн хангахыг Бурхан хүмүүсээс шаарддаг. Бие махбодтой болсон Бурханд дуулгавартай байхыг хүмүүсээс шаардахын нэг тал нь Түүний үгийг хэрэгжүүлэхтэй хамаатай, харин нөгөө тал нь Түүний хэвийн болон бодит байдалд дуулгавартай байж чадахтай хамаатай. Энэ хоёр нь хоёулаа туйлын байх ёстой. Энэ талуудын аль алийг хэрэгжүүлж чаддаг хүмүүс бол зүрх сэтгэлдээ Бурханыг гэх жинхэнэ хайр өвөрлөдөг бүх хүн юм. Тэд бол Бурханаар авхуулсан хүмүүс бөгөөд бүгд Бурханыг амь шигээ хайрладаг. Бие махбодтой болсон Бурхан хэвийн болон бодитой хүн чанараар ажилладаг. Ийм маягаар Түүний хэвийн болон бодитой хүн чанарын хоёулангийнх нь гадаад бүрхүүл хүмүүсийн хувьд үлэмж их шалгалт болдог; энэ нь тэдний хамгийн том хүндрэл бэрхшээл болдог. Гэсэн хэдий ч Бурханы хэвийн

болон бодит байдлаас зайлсхийх аргагүй. Бурхан шийдэл олохын тулд бүхнийг оролдож үзсэн боловч эцэст нь Өөрийгөө хэвийн хүн чанарынхаа гадаад бүрхүүлээс салгаж чадаагүй. Учир нь эцсийн эцэст нь Тэр бол тэнгэр дэх Сүнсний Бурхан биш, харин махбод болсон Бурхан билээ. Тэр бол хүмүүсийн харж чаддаггүй Бурхан биш, харин бүтээлийн нэг гишүүний бүрхүүлийг өмссөн Бурхан юм. Иймд Өөрийгөө хэвийн хүн чанарын бүрхүүлээс салгах нь яавч амархан байхгүй. Тиймээс ямар ч байсан Тэрээр хийхийг хүссэн ажлаа махан биеийн өнцгөөс хийсээр байдаг. Энэ ажил нь хэвийн болон бодитой Бурханы илэрхийлэл тул хүмүүс захирагдахгүй байвал яалаа гэж зүгээр байх юм бэ? Хүмүүс Бурханы үйлдлийн талаар яг юу хийж чадах юм бэ? Тэрээр хийхийг хүссэн юм болгоноо хийдэг; Тэр юунд ч баярладаг бай, тийм л байдаг. Хэрвээ хүмүүс дуулгавартай байхгүй юм бол тэдэнд өөр ямар эрүүл саруул төлөвлөгөө байх юм бэ? Одоог хүртэл дуулгавартай байдал л хүмүүсийг аварч байсан; хэнд ч, ямар ч мэргэн санаа байгаагүй. Хэрвээ Бурхан хүмүүсийг туршихыг хүсвэл тэд юу хийж чадах юм бэ? Гэхдээ энэ бүхэн нь тэнгэр дэх Бурханы бодол санаа биш; энэ бол бие махбодтой болсон Бурханы санаа юм. Тэр үүнийг хийхийг хүсдэг тул нэг ч хүн үүнийг өөрчилж чадахгүй. Тэнгэр дэх Бурхан бие махбодтой болсон Түүний хийдэг зүйлд хөндлөнгөөс оролцдоггүй, тэгвэл хүмүүс Түүнд бүр ч дуулгавартай байх ёстой бус уу? Хэдийгээр Тэр бодитой агаад хэвийн боловч тэр чигтээ махбод болсон Бурхан юм. Өөрийнхөө санаан дээр үндэслээд Тэр хүссэн болгоноо хийдэг. Тэнгэр дэх Бурхан бүх үүрэг даалгаврыг Түүнд шилжүүлэн өгсөн; чи Түүний хийдэг бүхэнд дуулгавартай байх ёстой. Хэдийгээр Тэр хүн чанартай бөгөөд тун хэвийн боловч энэ бүхэн нь Түүний зориуд зохицуулсан зүйл юм, иймээс хүмүүс Түүнийг яаж үл зөвшөөрсөн, гайхсан нүдээр ширтэн харж болох юм бэ? Тэр хэвийн байхыг хүсдэг, иймээс Тэр хэвийн байдаг. Тэрээр хүн чанарын дотор амьдрахыг хүсдэг, иймээс хүн чанарын дотор амьдардаг. Тэр бурханлаг чанарын дотор амьдрахыг хүсдэг, иймээс бурханлаг чанарын дотор амьдардаг. Хүмүүс үүнийг хүссэнээрээ харж болох боловч Бурхан үргэлж Бурхан, хүмүүс үргэлж хүмүүс байх болно. Зарим нэг ялимгүй зүйлээс болж Түүний мөн чанарыг үгүйсгэж болохгүй, мөн ганц жаахан зүйлээс болоод Түүнийг Бурханы “үнэн биеэс” түлхэн гаргаж ч болохгүй. Хүмүүст хүмүүний эрх чөлөө байдаг ба Бурханд Бурханы эрхэм чанар байдаг; эдгээр нь нэг нэгэндээ саад болдоггүй. Хүмүүс Бурханд бага зэрэг эрх чөлөө олгож чадахгүй гэж үү? Бурхан арай илүү хайхрамжгүй байхыг тэд тэвчиж чадахгүй гэж үү? Бурханд маш хатуу чанд бүү ханд! Дор бүрнээ нэг нэгнээ хүлцэх ёстой; тэгвэл бүх зүйл шийдэгдэхгүй гэж үү? Ямар нэгэн хөндий байдал байсаар байна гэж үү? Хэрвээ хүн тийм ялихгүй зүйлийг тэвчиж чадахгүй бол “Эр хүний дотор эмээл хазаартай морь багтдаг” гэх мэт зүйлийг хэлээд ч яах юм бэ? Тэд яаж жинхэнэ хүн байж чадах юм бэ? Бурхан хүн төрөлхтөнд бэрхшээл учруулдаг юм биш, харин хүн төрөлхтөн л Бурханд бэрхшээл учруулдаг. Тэд үргэлж туулайн чинээ цагааныг уулын чинээ хар

болгосноор аливааг зохицуулдаг. Тэд үнэхээр сүржигнэн дэгсдүүлдэг ба ингэх нь ямар ч хэрэггүй! Бурхан хэвийн болон бодитой хүн чанар дотор ажиллах үед Түүний хийдэг зүйл нь хүн төрөлхтний ажил биш, харин Бурханы ажил юм. Гэсэн ч хүмүүс Түүний ажлын мөн чанарыг хардаггүй; тэд үргэлж Түүний хүн чанарын гадаад бүрхүүлийг л хардаг. Тэд ийм агуу ажлыг хараагүй мөртөө Бурханы эгэл жирийн, хэвийн хүн чанарыг харахаар зүтгэдэг ба үүнийг тавьж явуулдаггүй. Үүнийг яаж Бурханд дуулгавартай байна гэж хэлж болох юм бэ? Тэнгэр дэх Бурхан одоо газар дээрх Бурхан “болж хувирсан” бөгөөд газар дээрх Бурхан бол одоо тэнгэр дэх Бурхан юм. Тэдний гадаад илрэлт адилхан эсэх нь, эсвэл Тэд яг яаж ажилладаг нь хамаагүй. Эцсийн эцэст Бурханы ажлыг хийдэг Нэгэн бол Бурхан Өөрөө юм. Чи хүссэн ч, хүсээгүй ч дуулгавартай байх ёстой—энэ нь чиний сонгох зүйл биш! Бурханд хүмүүс дуулгавартай байх ёстой ба өчүүхэн төдий ч дүр үзүүлэлгүйгээр Бурханыг туйлын дуулгавартай дагах ёстой.

Бие махбодтой болсон Бурханы өнөөдөр олж авахыг хүсдэг бүлэг хүмүүс бол Түүний хүсэлд нийцдэг хүмүүс юм. Тэд зөвхөн Түүний ажилд захирагдах хэрэгтэй бөгөөд тэнгэр дэх Бурханы тухай санаа бодолд байнга анхаарч, тодорхойгүй байдалд амьдарч, махбод дахь Бурханд бэрхшээл учруулахаа болих хэрэгтэй. Түүнийг дуулгавартай дагаж чаддаг хүмүүс бол Түүний үгийг заавал сонсож, Түүний зохицуулалтад захирагддаг хүмүүс юм. Ийм хүмүүс тэнгэр дэх Бурхан үнэндээ яг ямар болох, эсвэл тэнгэр дэх Бурхан хүн төрөлхтний дунд одоогоор ямархуу ажил хийж байж болохыг огтхон ч анхаардаггүй; харин газар дээрх Бурханд зүрх сэтгэлээ бүрэн өгч, бүхий л оршихуйгаа Түүний өмнө тавьдаг. Тэд өөрсдийнхөө аюулгүй байдлыг хэзээ ч анхаардаггүй, бие махбодтой болсон Бурханы хэвийн агаад бодит байдлын талаар хэзээ ч төвөг уддаггүй. Махбод дахь Бурханд захирагддаг хүмүүс Түүгээр төгс болгуулж чадна. Тэнгэр дэх Бурханд итгэдэг хүмүүс юу ч олж авахгүй. Учир нь тэнгэр дэх Бурхан биш, харин газар дээрх Бурхан л хүмүүст амлалт, ерөөл хайрладаг билээ. Хүмүүс тэнгэр дэх Бурханыг үргэлж агуу хэмээн үзэж, газар дээрх Бурханыг эгэл жирийн хүн мэт үзэх ёсгүй; энэ нь шударга бус. Тэнгэр дэх Бурхан бол ер бусын мэргэн ухаантай агуу агаад гайхалтай атлаа огтхон ч оршин байдаггүй; газар дээрх Бурхан тун жирийн агаад шалихгүй; бас маш хэвийн. Түүнд ер бусын оюун ухаан юм уу газар донсолгом үйл үйлддэггүй; Тэр зүгээр л тун хэвийн, бодитой байдлаар ажиллаж, үгээ хэлдэг. Тэр аянгаар дамжуулан ярьдаггүй, эсвэл салхи бороог захирдаггүй ч гэсэн үнэхээр бие махбодтой болсон тэнгэр дэх Бурхан бөгөөд хүмүүсийн дунд амьдарч буй Бурхан үнэхээр мөн. Хүмүүс өөрсдийн ойлгож чадах, өөрсдийнх нь төсөөлөлд таарсан нэгнийг Бурхан гэж дөвийлгөөд, харин өөрсдийнхөө хүлээн зөвшөөрч чадахгүй, огтхон ч төсөөлж чадахгүй нэгнийг дорд хэмээн үзэх ёсгүй. Энэ бүхэн хүмүүсийн тэрслүү байдлаас урган гардаг; энэ нь Бурханыг эсэргүүцдэг хүн төрөлхтний эсэргүүцлийн бүх эх сурвалж юм.

ТӨГС БОЛГУУЛАХ ХҮМҮҮС ЦЭВЭРШҮҮЛЭЛТ ТУУЛАХ ЁСТОЙ

Чи Бурханд итгэдэг бол Бурханыг дуулгавартай дагаж, үнэнийг хэрэгжүүлэн бүх үүргээ биелүүлэх ёстой. Үүнээс гадна чи туршлагажих хэрэгтэй зүйлсээ ойлгох ёстой. Чи зөвхөн харьцалт, сахилгажуулалт, шүүлтийг туулж, Бурханд дуртай байж чаддаг мөртөө Бурхан чамайг сахилгажуулж, чамтай харьцаж байгааг мэдэрч чадахгүй л байгаад байх юм бол энэ чинь хүлээн зөвшөөрөхийн аргагүй зүйл юм. Магадгүй энэ удаагийн цэвэршүүлэлтэд чи дороо бат зогсож чадах ч энэ чинь бас л хангалтгүй; чи урагш алхсаар байх ёстой. Бурханыг хайрлах хичээл хэзээ ч дуусдаггүй бөгөөд эцэс төгсгөл гэж үгүй. Бурханд итгэх нь туйлын энгийн зүйл гэж хүмүүс үздэг боловч бодитой туршлага олж авмагцаа Бурханд итгэх итгэл нь хүмүүсийн төсөөлдөг шиг хялбар зүйл биш гэдгийг ухамсарладаг. Бурхан хүнийг цэвэршүүлэхээр ажиллах үед хүн зовдог. Хүний цэвэршүүлэлт их байх тусам түүний Бурханыг хайрлах хайр өсөн нэмэгдэж, Бурханы сүр хүч түүнд илүү ихээр илчлэгдэх болно. Эсрэгээрээ, хүн цэвэршүүлэлт бага хүртэх тусам Бурханыг хайрлах түүний хайр өсөн нэмэгдэх нь багасаж, Бурханы сүр хүч түүнд илчлэгдэх нь ч багасна. Хүний цэвэршүүлэлт, зовлон шаналал их байх тусам, тарчлалыг илүү их туулах тусам, түүний Бурханыг хайрлах хайр улам гүнзгийрч, Бурханд итгэх итгэл нь илүү үнэн бодитой, Бурханы талаарх мэдлэг нь илүү гүн гүнзгий болдог. Цэвэршүүлэгдэх явцдаа ихээхэн зовж, ихээхэн харьцалт, сахилгажуулалт туулсан хүмүүс Бурханыг гүнзгий хайрладаг, Бурханы талаар илүү гүн гүнзгий, нэвтэрхий мэдлэгтэй байдгийг чи туршлагаараа харна. Харин харьцалт туулаагүй хүмүүс өнгөцхөн мэдлэгтэй байдаг бөгөөд тэд “Бурхан үнэхээр сайн, Тэр хүмүүст нигүүлсэл хайрладаг болохоор хүмүүс Түүнд дуртай байдаг” гэж хэлэхээс хэтэрдэггүй. Хүмүүс харьцалт, сахилгажуулалт туулбал Бурханы талаарх жинхэнэ мэдлэгийн тухай ярих чадвартай болдог. Тиймээс хүнд хийх Бурханы ажил гайхалтай байх тусмаа илүү үнэ цэн, ач холбогдолтой байдаг. Чиний хувьд ухаарахын аргагүй, үзэлтэй чинь нийцэшгүй байх тусмаа Бурханы ажил чамайг илүү их байлдан дагуулж, олж авч, төгс болгож чаддаг. Бурханы ажлын ач холбогдол хэчнээн их билээ! Хэрэв Бурхан хүнийг ийм байдлаар цэвэршүүлээгүй, энэхүү арга барилын дагуу ажиллаагүй бол Түүний ажил үр дүнгүй, ач холбогдолгүй байх байсан. Бурхан энэ бүлэг хүмүүсийг сонгож, олж аваад, эцсийн өдрүүдэд бүрэн төгс болгоно хэмээн урьд өмнө нь яригдаж байсан; үүнд ер бусын ач холбогдол бий. Бурханы та нарын дотор хийдэг ажил агуу байх тусам Бурханыг хайрлах та нарын хайр илүү гүнзгий, ариун байх юм. Бурханы ажил агуу байх тусам хүн Түүний мэргэн ухаанаас төдий чинээ ихийг ухаарч чадах ба Бурханы талаарх хүний мэдлэг төдий чинээ гүнзгийрдэг. Эцсийн өдрүүдэд Бурханы удирдлагын төлөвлөгөөний зургаан мянган жил төгсгөл болно. Тийм амархан төгсөж чадах болов уу? Тэр хүн төрөлхтнийг байлдан дагуулмагц Түүний ажил дуусах уу? Ийм хялбар байж болно гэж үү? Хүмүүс үнэхээр ийм л

хялбар хэмээн төсөөлдөг боловч Бурханы хийдэг зүйл тийм ч хялбар биш юм. Чи Бурханы ажлын аль ч хэсгийг дурдсан бай хүний хувьд бүгд ойлгохын аргагүй юм. Хэрэв чи үүнийг ухан ойлгож чаддаг байсан бол Бурханы ажил ач холбогдолгүй, үнэ цэнгүй байх байлаа. Бурханы хийсэн ажлыг ойлгохын аргагүй; чиний үзлээс тэс ондоо юм. Чиний үзэлтэй нийцэхгүй байх тусам Бурханы ажил ямар их утга учиртай болох нь илүү их харагддаг; чиний үзэлтэй таардаг байсан бол утга учиргүй байх байлаа. Өнөөдөр чи Бурханы ажил үнэхээр гайхалтай болохыг мэдэрдэг бөгөөд гайхалтай гэдгийг нь мэдрэх тусам Бурхан чамд улам ойлгохын аргагүй санагдаж, Бурханы үйл хэрэг ямар агуу болохыг чи хардаг. Хэрэв Тэр хүнийг байлдан дагуулахын тулд хэдхэн өнгөцхөн, хааш яаш ажил хийгээд л дараа нь юу ч хийгээгүй бол хүн Бурханы ажлын ач холбогдлыг олж харж чадахгүй байх байсан. Одоо чи бага зэргийн цэвэршүүлэлт хүлээн авч байгаа ч энэ нь амийн өсөлтөд чинь асар их ашиг тустай; тиймээс ийм бэрхшээл зовлон туулах нь та нарт нэн чухал шаардлагатай билээ. Өнөөдөр чи багахан цэвэршүүлэлт хүлээн авч байгаа ч дараа нь чи Бурханы үйл хэргийг үнэхээр олж харж чаддаг болж, эцэст нь “Бурханы үйл хэрэг үнэхээр гайхалтай юм аа!” гэж хэлнэ. Энэ нь чиний зүрх сэтгэл дэх үгс байх болно. Бурханы цэвэршүүлэлтийг хэсэг хугацаанд туулаад (үйлчлэл үзүүлэгчдийг шалгах шалгалт ба гэсгээлтийн цаг үе) зарим хүн эцэст нь “Бурханд итгэх үнэхээр хэцүү!” гэж хэлсэн. Тэд “үнэхээр хэцүү” гэдэг үгийг хэрэглэсэн нь Бурханы үйлдлүүдийг ойлгохын аргагүй, Бурханы ажил маш их ач холбогдол, үнэ цэнтэй бөгөөд хүн Түүний ажлыг эрхэмлэвэл туйлын зохилтой болохыг үнэндээ харуулж байна. Намайг тийм их ажил хийсний дараа чи өчүүхэн ч мэдлэг эзэмшээгүй байвал Миний ажил үнэ цэнтэй хэвээр байж чадах уу? Энэ нь чамайг “Бурханд үйлчлэх үнэхээр хэцүү, Бурханы үйлдлүүд үнэхээр гайхалтай, Бурхан үнэхээр мэргэн ухаантай! Бурхан их хайр татам юм!” гэж хэлэхэд хүргэнэ. Хэрэв туршлагажих үеийг туулсныхаа дараа чи ийм үг хэлж чадаж байвал Бурханы ажлыг олж авсныг чинь энэ нотолж байгаа юм. Нэг өдөр хилийн чанадад сайн мэдээ түгээж байхад чинь хэн нэгэн чамаас “Чиний Бурханд итгэх итгэл хэр байна?” гэж асуувал чи “Бурханы үйлдэл үнэхээр гайхамшигтай!” гэж хэлж чадна. Хүмүүс чиний үг бодит туршлагыг илэрхийлж буйг мэдрэх болно. Энэ л үнэхээр гэрчлэл хийж буй явдал юм. Бурханы ажил мэргэн ухаанаар дүүрэн, Түүний чамд хийсэн ажил чамайг бүрэн үнэмшүүлж, зүрх сэтгэлийг чинь байлдан дагуулсан гэж чи хэлнэ. Чи Түүнийг үргэлж хайрлах болно. Учир нь Тэр хүн төрөлхтний хайрыг хүртэх хангалттай гавьяатай! Хэрэв чи ийм зүйлсийг ярьж чадвал хүмүүсийн зүрх сэтгэлийг хөдөлгөж чадна. Энэ бүгд нь гэрчлэл хийж буй хэрэг юм. Хэрэв чи цангинасан гэрчлэл хийж, хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөн уйлуулж чадвал энэ нь Бурханд хайртай нэгэн мөн болохыг чинь харуулдаг. Учир нь чи Бурханд хайртайгаа гэрчилж чаддаг, чамаар дамжин Бурханы үйлдэл гэрчлэгдэж чаддаг билээ. Чиний гэрчлэлээр дамжуулан бусад хүн Бурханы ажлыг эрж хайн, туулах болсон бөгөөд ямар ч орчинд туулдаг байсан тэд бат зогсож чадна. Энэ бол гэрчлэл хийх цорын ганц жинхэнэ зам бөгөөд чамаас

одоо яг үүнийг л шаарддаг. Бурханы ажил туйлын үнэ цэнтэй бөгөөд хүмүүс үүнийг нандигнах учиртай, Бурхан бол маш эрхэм нандин бөгөөд элбэг дэлбэг болохыг чи олж харах ёстой; Тэр үг хэлж чаддаг төдийгүй бас хүмүүсийг шүүж, зүрх сэтгэлийг нь цэвэршүүлж, тэдэнд баяр баясгалан авчирч, тэднийг олж авч, байлдан дагуулж, төгс болгож чадна. Бурхан ихэд хайр татам гэдгийг чи өөрийн туршлагаас харна. Тэгэхээр чи одоо Бурханыг хэр их хайрладаг вэ? Эдгээр зүйлийг чи үнэхээр зүрх сэтгэлээсээ хэлж чадах уу? Чи энэ үгийг зүрх сэтгэлийнхээ гүнээс илэрхийлж чаддаг болох үедээ л гэрчлэл хийж чаддаг болно. Туршлага чинь энэ түвшинд хүрсэн цагт чи Бурханыг гэрчлэгч байх чадвартай болох бөгөөд шаардлага хангахуйц болсон байна. Чи туршлагаараа энэ түвшинд хүрэхгүй бол болоогүй л байна гэсэн үг. Цэвэршүүлэлтийн явцад хүмүүс сул дорой байдал гаргах нь жирийн үзэгдэл боловч цэвэршүүлэлтийн дараа чи “Бурхан маш ухаалгаар ажилдаг юм байна!” гэж хэлж чадах учиртай. Эдгээр үгийн бодит ойлголтод чи үнэхээр хүрч чадсан бол энэ нь чиний нандигнадаг зүйлс болж, чиний туршлага үнэ цэнтэй болно.

Одоо чи юуг эрэлхийлэх ёстой вэ? Чи Бурханы ажлыг гэрчлэх чадвартай эсэх, Бурханы гэрчлэл болон илрэл болж чадах эсэх, Бурханаар ашиглуулахад тохирох эсэх—эдгээр нь чиний эрж хайх ёстой зүйлс юм. Бурхан яг хэр их ажил чамд хийсэн бэ? Хэр ихийг чи харж, хэр их нь чамд хүрсэн бэ? Хэр ихийг чи туулж, амссан бэ? Бурхан чамайг туршиж, чамтай харьцаж, чамайг сахилгажуулж байсан эсэхээс үл хамааран Түүний үйлдэл, ажил чам дээр хэрэгжиж ирсэн. Гэвч Бурханд итгэгч бөгөөд Бурханаар төгс болгуулахыг эрэлхийлэхэд бэлэн хүний хувьд чи бодитой туршлага дээрээ үндэслэн Бурханы ажлыг гэрчилж чаддаг уу? Чи бодитой туршлагаараа Бурханы үгийг амьдран харуулж чаддаг уу? Чи бодитой туршлагаараа дамжуулан бусдыг хангаж, Бурханы ажлыг гэрчлэхэд бүхий л амьдралаа зарлагадаж чаддаг уу? Бурханы ажилд гэрчлэл хийхдээ чи туршлага, мэдлэг, төлсөн төлөөсөндөө найдах ёстой. Ингэж байж л Түүний хүслийг гүйцэлдүүлж чадна. Чи Бурханы ажилд гэрчлэл хийдэг хүн мөн үү? Чамд ийм эрмэлзэл бий юу? Хэрэв чи Түүний нэрийг, цаашлаад Түүний ажлыг гэрчилж чаддаг, Өөрийнхөө хүмүүсээс Түүний шаарддаг дүр төрхийг амьдран харуулж чаддаг бол чи Бурханыг гэрчлэгч мөн билээ. Чи Бурханд яг хэрхэн гэрчлэл хийдэг вэ? Бурханы үгийг амьдран харуулахаар эрж хайж, тэмүүлэн, өөрийн үгээр гэрчлэл хийж, хүмүүст Түүний ажлыг мэдүүлж, Түүний үйлдлийг харуулснаараа үүнийг хийдэг. Хэрэв чи энэ бүхнийг үнэхээр эрж хайвал, Бурхан чамайг төгс болгоно. Хэрэв чи зөвхөн Бурханаар төгс болгуулж, эцэс төгсгөлд нь ерөөгдөхийн төлөө л эрж хайдаг бол Бурханд итгэх итгэлийн чинь харах өнцөг цэвэр биш байна. Чи, Бурханы үйл хэргийг бодит амьдрал дээр хэрхэн харахыг, чамд хүслээ илчлэх үед нь Түүнийг хэрхэн сэтгэл хангалуун байлгахыг эрэлхийлэх ёстой; Түүний гайхалтай байдал, мэргэн ухааныг хэрхэн гэрчлэхийг, Тэр яаж чамайг сахилгажуулж, чамтай харьцдагийг хэрхэн гэрчлэхийг эрэлхийлэх ёстой. Энэ бүхэн нь одоо чиний тунгаан бодож байх ёстой зүйл юм. Бурханыг хайрлах хайр чинь гагцхүү төгс болгуулсныхаа

дараа Бурханы алдрыг хуваалцаж чаддаг байхын төлөө юм бол энэ нь бас л хангалтгүй бөгөөд Бурханы шаардлагад нийцэж чадахгүй. Чи Бурханы ажилд гэрчлэл хийж, Түүний шаардлагыг хангаж, хүмүүс дээр хийсэн Түүний ажлыг бодитойгоор туулж чаддаг байх хэрэгтэй. Өвчин, нулимс, гунигийн аль нь ч бай чи энэ бүгдийг хэрэгжүүлэлтээрээ туулах ёстой. Эдгээр нь чамайг Бурханыг гэрчилдэг нэгэн болгож төгс болгох учиртай юм. Чи одоо яг юунаас болоод зовж, төгс болгуулахаар эрж хайдаг вэ? Одоогийн зовлон зүдүүр чинь үнэхээр Бурханыг хайрлаж, Түүнийг гэрчлэхийн төлөө байдаг уу? Эсвэл энэ нь махан биеийн ерөөл, хэтийн ирээдүй, хувь заяаны чинь төлөө байдаг уу? Чи бүх санаа зорилго, сэдэл, эрэлхийлдэг зорилгоо залруулах ёстой бөгөөд өөрийн хүсэлд хөтлөгдөж болохгүй. Нэг нь ерөөл хүртэж, эрх мэдлээр ноёрхохын тулд төгс болгуулахыг эрж хайдаг байхад нөгөө нь Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, Бурханы ажилд бодитой гэрчлэл хийхийн тулд төгс болгуулахыг эрэлхийлдэг бол энэ хоёр эрэл хайгуулын арга замаас чи алийг нь сонгох байсан бэ? Хэрэв чи эхнийхийг нь сонгосон бол Бурханы стандартад хүрэхэд бас л хэтэрхий хол байх болно. Орчлон ертөнц даяар Миний үйлдлийг ил тод мэдэх болно, орчлон ертөнцөд Би Хаан сууна гэж Би нэгэнтээ хэлсэн. Нөгөөтээгүүр, та нарт даалгасан зүйл бол гадуур явж Бурханы ажилд гэрчлэл хийх болохоос хаад болж, бүхий л орчлон ертөнцөд харагдах биш юм. Бурханы үйл хэргээр сансар болон тэнгэр огторгуйг дүүргүүл. Хүн бүрд үүнийг харуулж, хүлээн зөвшөөрүүл. Эдгээр үгийг Бурханд Өөрт нь хамааруулан хэлсэн бөгөөд хүмүүсийн хийх ёстой зүйл бол Бурханы төлөө гэрчлэл хийх билээ. Бурханы талаар чи одоо хэр ихийг мэддэг вэ? Бурханы талаар чи одоо хэр ихийг гэрчилж чадах вэ? Бурхан хүнийг төгс болгохын зорилго юу вэ? Бурханы хүслийг ойлгомогцоо чи Түүний хүсэлд хэрхэн санаа тавих ёстой вэ? Хэрэв чи төгс болгуулж, амьдран харуулдаг зүйлээрээ Бурханы ажилд гэрчлэл хийхийг хүсэж байгаа бол, чамд ийм хөдөлгөх хүч байгаа бол, юу ч хэтэрхий хэцүү биш. Хүмүүст одоо хэрэгтэй байгаа зүйл бол итгэл юм. Хэрэв чамд ийм хөдөлгөх хүч байгаа бол аливаа сөрөг байдал, идэвхгүй байдал, залхуурал болон махан биеийн үзэл, амьдралын гүн ухаан, тэрслүү зан чанар, сэтгэл хөдлөл гэх мэтээ орхиход хялбар байдаг.

Шалгалтыг туулж байхдаа хүмүүс сул дорой болж, дотроо сөрөг байдал тээж, Бурханы хүсэл болон хэрэгжүүлэлтийн замыг ойлгож чадахгүй байх нь хэвийн юм. Гэвч ямар ч тохиолдолд чи Бурханы ажилд итгэлтэй байж, яг л Иов шиг Бурханыг үгүйсгэхгүй байх ёстой. Хэдийгээр Иов сул дорой байж, төрсөн өдрөө хараасан боловч Ехова хүний амьдрал дахь бүх зүйлийг хайрласан, мөн Ехова бол тэднийг бүгдийг нь авч явах Нэгэн мөн гэдгийг тэр үгүйсгээгүй. Түүнийг яаж ч шалгасан тэр энэ итгэлээ хадгалсан. Туршлагынхаа явцад чи Бурханы үгээр дамжуулан ямар цэвэршүүлэлт туулах нь хамаагүй, хүн төрөлхтнөөс Бурханы шаарддаг зүйл бол товчхондоо тэдний итгэл, Өөрийг нь гэх хайр юм. Ийм байдлаар ажилласнаараа Тэр хүмүүсийн итгэл, хайр, тэмүүллийг төгс болгодог. Бурхан төгс болгох ажлыг хүмүүс дээр хийдэг бөгөөд хүмүүс үүнийг харж, мэдэрч чаддаггүй; ийм нөхцөлд

чиний итгэл шаардлагатай. Юмыг энгийн нүдээр харах боломжгүй үед хүмүүст итгэл шаардлагатай болдог бөгөөд үзлээ орхиж чадахгүй үед чинь чамд итгэл хэрэгтэй байдаг. Бурханы ажлын талаар тодорхой ойлголтгүй байх үедээ чиний хийх ёстой зүйл бол итгэлтэй байж, дороо бат зогсож, гэрчлэлд зогсох хэрэгтэй. Иов энэ цэгт хүрэх үед Бурхан түүнд харагдаж, түүнтэй ярьсан. Өөрөөр хэлбэл, итгэл дотроосоо л чи Бурханыг харж чадах бөгөөд итгэл байгаа цагт Бурхан чамайг төгс болгоно. Итгэл үгүй бол Тэр үүнийг хийж чадахгүй. Чиний олж авахаар найдаж байгаа бүхнийг Бурхан чамд хайрлана. Чамд итгэл байхгүй бол төгс болгуулж чадахгүй бөгөөд чи Бурханы үйлсийг харж чадахгүй, Түүний төгс хүчийг харж бүр ч чадахгүй. Бодитой туршлагаараа Түүний үйлдлийг харна гэсэн итгэл чамд байгаа үед Бурхан чамд харагдаж, Тэр чамайг дотроос чинь гэгээрүүлж, чиглүүлэх болно. Ийм итгэл үгүй бол Бурхан үүнийг хийж чадахгүй. Хэрэв чи Бурханд найдах найдвараа алдсан бол Түүний ажлыг хэрхэн туулж чадах юм бэ? Тиймээс чамд итгэл байгаа бөгөөд Бурханд эргэлзэх эргэлзээ тээгээгүй үед л, Түүнийг юу ч хийсэн, Түүнд итгэх жинхэнэ итгэл чамд байгаа үед л туршлагаар чинь дамжуулан Тэр чамайг гэгээрүүлж, гэрэлтүүлэх бөгөөд тэр цагт л чи Түүний үйлдлийг харж чадна. Энэ бүхэнд бүгдэд нь итгэлээр дамжуулан хүрдэг. Итгэл зөвхөн цэвэршүүлэлтээр дамжин ирдэг бөгөөд цэвэршүүлэлт байхгүй бол итгэл бий болж чадахгүй. “Итгэл” хэмээх энэхүү үг юуг хэлдэг вэ? Итгэл гэдэг нь аливаа зүйлийг харж, барьж чадахгүй үед, Бурханы ажил хүний үзэлтэй нийцэхгүй үед, хүн хүрэхийн аргагүй үед хүнд байх ёстой жинхэнэ итгэл үнэмшил, чин үнэн зүрх сэтгэл юм. Энэ бол Миний ярьдаг итгэл юм. Бэрхшээл зовлон, цэвэршүүлэлтийн цаг үед хүмүүст итгэл хэрэгтэй бөгөөд итгэл нь цэвэршүүлэлтийг дагаж ирдэг зүйл юм; цэвэршүүлэлт, итгэл хоёрыг салгах боломжгүй. Бурхан яаж ч ажилласан, орчин нөхцөл чинь ямар ч байсан чи амийг эрэлхийлж, үнэнийг эрж хайж, Бурханы ажлын талаарх мэдлэгийг эрж хайж, Түүний үйлдлийн талаар ойлголттой байж, үнэний дагуу үйлдэж чаддаг. Ингэх нь жинхэнэ итгэлтэй байх явдал бөгөөд үүгээрээ чи Бурханд итгэх итгэлээ алдаагүй гэдгээ харуулдаг. Цэвэршүүлэлтээр дамжуулан үнэнийг эрэлхийлэхдээ туйлбартай байж чаддаг бол, Бурханыг үнэхээр хайрлаж чаддаг, Түүнд хэзээ ч эргэлздэггүй бол, Тэр юу ч хийсэн Түүнийг сэтгэл хангалуун байлгахын тулд үнэнийг хэрэгжүүлсээр байдаг бол, Түүний хүслийг гүн гүнзгий эрж хайж, Түүний хүсэлд санаа тавьж чаддаг бол чи Бурханд итгэх жинхэнэ итгэлтэй байж чадна. Урьд нь чамайг хаан суух болно гэж Бурхан айлдахад чи Түүнийг хайрласан бөгөөд Тэр чамд Өөрийгөө ил тод харуулахад чи Түүнийг эрж хайсан. Гэвч одоо Бурхан нуугдсан, Түүнийг харж чадахгүй, чамд саад тотгор таарсан энэ үед чи одоо Бурханд найдах найдвараа алдах уу? Тэгэхээр чи цаг үргэлж амийг эрэлхийлж, Бурханы хүслийг хангахаар эрж хайх ёстой. Үүнийг л жинхэнэ итгэл гэдэг бөгөөд энэ бол хамгийн үнэн, хамгийн сайхан хайр билээ.

Урьд нь хүмүүс амлалтаа өгөхөөр Бурханы өмнө бүгд ирж “Өөр хэн ч Бурханыг хайрладаггүй байсан ч гэсэн би Түүнийг хайрлах ёстой” гэж хэлдэг байсан. Гэвч

одоо цэвэршүүлэлт чам дээр ирж, энэ нь чиний үзэлтэй нийцэхгүй болохоор чи Бурханд итгэх итгэлээ алддаг. Энэ жинхэнэ хайр мөн гэж үү? Иовын үйл хэргийн тухай чи олон удаа уншиж байсан байж тэр талаар мартлаа гэж үү? Жинхэнэ хайр итгэл дотроос л хэлбэрээ олдог. Чиний туулдаг цэвэршүүлэлтээр дамжин Бурханыг гэх бодит хайр чинь бий болдог бөгөөд чи итгэлээрээ дамжуулан бодитой туршлагадаа Бурханы хүсэлд санаа тавьж чаддаг ба мөн л итгэлээр дамжуулан махан биеэ хаяж, амийг эрж хайдаг; энэ бол хүмүүсийн хийх ёстой зүйл юм. Хэрэв чи үүнийг хийдэг бол Бурханы үйлдлийг харж чаддаг болно, харин чамд итгэл дутагдаж байвал Бурханы үйлдлийг харж, Түүнийг ажлыг туулж чадахгүй. Бурханаар ашиглуулж, төгс болгуулахыг хүсдэг бол зовж зүдрэх хүсэл, итгэл, тэсвэр хатуужил, дуулгавартай байдал, Бурханы ажлыг туулах, Түүний хүслийг ухаж ойлгох, Түүний уй гашуунд санаа тавих чадвар гээд бүгдийг чи эзэмших ёстой. Хүнийг төгс болгох хялбар биш бөгөөд туулсан цэвэршүүлэлт бүр чинь чамаас итгэл, хайр шаарддаг. Чи Бурханаар төгс болгуулахыг хүсдэг бол замаар ердөө хурдлан урагшлах нь хангалтгүй, Бурханы төлөө ердөө өөрийгөө зарлагадах ч бас хангалтгүй. Бурханаар төгс болгуулдаг хүн болж чадахын тулд чи олон зүйлийг эзэмших ёстой. Зовлон зүдүүртэй тулгарах үедээ чи махан биеийн төлөөх зовнилоо хойш тавьж, Бурханы эсрэг гомдол гаргахгүй байж чаддаг байх ёстой. Бурхан Өөрийгөө чамаас нуух үед Түүнийг дагах итгэлтэй байж, урьдын хайраа бөхөөж, сарниулалгүйгээр хадгалж чаддаг байх ёстой. Бурхан юу ч хийсэн чи Түүний зохицуулалтад захирагдаж, Түүний эсрэг гомдол гаргахаасаа илүү махан биеэ хараахад бэлэн байх ёстой. Чи шалгалттай тулгарах үедээ хэдийгээр гашуун нулимс унагаж, хайртай эд зүйлээсээ хагацах дургүй байсан ч гэсэн Бурханыг сэтгэл хангалуун болгох ёстой. Энэ л жинхэнэ хайр, итгэл билээ. Чиний жинхэнэ биеийн хэмжээ ямар ч байсан гэсэн бэрхшээл зовлонг эдлэх хүсэл болон жинхэнэ итгэлийн аль алиныг нь чи эхлээд эзэмших ёстой бөгөөд махан биеийг хаях хүсэл мөн чамд байх ёстой. Чи Бурханы хүслийг хангахын тулд хувийн бэрхшээл зовлонг тэсэж даван, хувийн ашиг сонирхолдоо хохирол амсахад бэлэн байх хэрэгтэй. Мөн чи өөртөө харамсаж чаддаг байх ёстой: Урьд нь чи Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаггүй байсан, одоо өөртөө харамсаж чадна. Эдгээрийн аль нь ч чамд дутагдах ёсгүй—ийм зүйлсээр дамжуулан Бурхан чамайг төгс болгоно. Хэрэв чи эдгээр шалгуурыг хангаж чадахгүй бол төгс болгуулж чадахгүй.

Бурханд үйлчилдэг хүн Түүний төлөө хэрхэн зовохыг л гагцхүү мэддэг байх ёсгүй; түүгээр зогсохгүй Бурханд итгэх нь Бурханыг хайрлах хайрыг эрэлхийлэх зорилготой гэдгийг ойлгох ёстой. Бурхан чамайг зөвхөн цэвэршүүлэх гэж, эсвэл зовоохын төлөө ашигладаггүй, харин чамайг Түүний үйлдлийг мэдэж, хүний амийн жинхэнэ ач холбогдлыг мэдээсэй, тэр тусмаа Бурханд үйлчлэх амар ажил биш гэдгийг мэдээсэй гэсэндээ ашигладаг. Бурханы ажлыг туулах нь нигүүлслийг эдлэх биш, харин Бурханыг хайрлах хайрынхаа төлөө зовох юм. Чи Бурханы нигүүлслийг эдэлдэг юм чинь Түүний гэсгээлтийг ч бас эдлэх ёстой; чи энэ бүхнийг туулах ёстой.

Чи Бурханы гэгээрлийг дотроо мэдэрч чадна, Тэр чамтай хэрхэн харьцаж, шүүж байгааг мөн туулж чадна. Ингэснээр чиний туршлага иж бүрэн болно. Бурхан шүүлт, гэсгээлтийн ажлаа чам дээр хэрэгжүүлсэн. Бурханы үг чамтай харьцсан, түүгээр ч барахгүй мөн чамайг гэгээрүүлж, гэрэлтүүлсэн. Чамайг сөрөг, сул дорой байх үед Бурхан чиний төлөө санаа зовдог. Энэ бүх ажил нь хүний бүх зүйл Бурханы зохион байгуулалтын дотор байдаг гэдгийг чамд мэдүүлэхийн тулд юм. Бурханд итгэх гэдэг нь зовох, эсвэл Түүний төлөө төрөл бүрийн юм хийх явдал гэж чи бодож болох юм; Бурханд итгэхийн зорилго нь махан бие чинь амар тайван байх, чиний амьдралын бүх зүйл төвөггүй байх, эсвэл бүх зүйлд амгалан, тав тухтай байхын тулд байдаг гэж ч бодож болно. Гэхдээ эдгээрийн аль нь ч хүмүүсийн Бурханд итгэх итгэлтэйгээ холбох ёстой зорилго биш юм. Хэрэв чи эдгээр зорилгын төлөө итгэдэг бол харах өнцөг чинь буруу бөгөөд чамайг төгс болгох угаас боломжгүй. Бурханы үйлдэл, Бурханы зөвт зан чанар, Түүний мэргэн ухаан, Түүний үг, Түүний гайхалтай байдал, ойлгошгүй байдал нь бүгд хүмүүсийн ойлгох учиртай зүйлс юм. Чи ийм ойлголтоор дамжуулан өөрийн зүрх сэтгэл дэх бүх хувийн хүсэлт, найдвар, үзлийг арилгаж болох юм. Эдгээрийг арилгаснаар л Бурханы шаардлагад нийцэж чадна, ингэснээр л чи амьтай болж, Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадна. Бурханд итгэх нь Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, Түүний шаарддаг зан чанарыг амьдран харуулах зорилготой байдаг, ингэснээр Түүний үйлдэл, алдар энэхүү ямар ч үнэ цэнгүй бүлэг хүнээр дамжин илэрч болох юм. Энэ бол Бурханд итгэх зөв харах өнцөг бөгөөд мөн чиний эрж хайх ёстой зорилт юм. Чи Бурханд итгэх талаар зөв үзэл бодолтой байж, Бурханы үгийг олж авахаар эрж хайх ёстой. Чи Бурханы үгийг идэж, уух хэрэгтэй, үнэнийг амьдран харуулж чаддаг байх ёстой, ялангуяа Түүний бодитой үйл хэрэг, орчлон даяарх гайхамшигтай үйл хэрэг, мөн махбодод хийдэг бодитой ажлыг нь харж чаддаг байх ёстой. Хүмүүс бодитой туршлагаараа дамжуулан Бурхан Өөрийн ажлыг тэдэн дээр яг хэрхэн хийдэг, тэдэнд чиглэсэн Түүний хүсэл юу болохыг үнэлж чадна. Энэ бүгд нь хүмүүсийн завхарсан сатанлаг зан чанарыг таягдан хаях зорилготой юм. Дотроо байгаа бүх цэвэр бус байдал, зөвт бус байдлыг хаяж, буруу санаа зорилгоо хаяж, Бурханд итгэх жинхэнэ итгэлийг бий болгосноор, жинхэнэ итгэлээр л чи Бурханыг үнэхээр хайрлаж чадна. Бурханд итгэх итгэлийнхээ суурин дээр л чи Түүнийг жинхэнээсээ хайрлаж чадна. Бурханд итгэхгүйгээр Түүнийг хайрлаж чадах уу? Чи Бурханд итгэдэг болохоор энэ талаар мунгинаад байж болохгүй. Зарим хүн Бурханд итгэх итгэл тэдэнд ерөөл авчирна гэдгийг харангуутаа эрч хүчээр дүүрэн болдог боловч цэвэршүүлэлтийг эдлэх ёстой гэдгийг харангуутаа бүх эрч хүчээ алддаг. Энэ нь Бурханд итгэх мөн үү? Эцсийн дүнд итгэлдээ чи Бурханы өмнө бүрэн дүүрэн дуулгавартай дагадаг болох ёстой. Чи Бурханд итгэдэг мөртөө Түүнээс юм нэхсээр байдаг, тавьж чадахгүй шашны олон үзэл, салж чадахгүй хувийн ашиг сонирхол чамд байдаг, махан биеийн ерөөлийг эрж хайсаар байдаг, махан биеийг чинь аварч, сүнсийг чинь аврахыг Бурханаас хүсдэг бол эдгээр нь

бүгд харах өнцөг нь буруу хүмүүсийн зан авир юм. Шашны итгэл үнэмшилтэй хүмүүс Бурханд итгэдэг хэдий ч зан чанараа өөрчлөхөөр эрж хайдаггүй, Бурханыг мэдэхээр эрэлхийлдэггүй, харин махан биеийн ашиг сонирхлын араас л хөөцөлддөг. Та нарын дотор олон хүн шашны итгэл үнэмшлийн ангилалд хамаарах итгэлтэй байдаг; энэ бол Бурханд итгэх жинхэнэ итгэл биш юм. Бурханд итгэхийн тулд хүмүүс Түүний төлөө зовоход бэлэн зүрх сэтгэл, өөрийгөө хаях хүсэлтэй байх ёстой. Хүмүүс энэ хоёр нөхцөлийг хангахгүй л бол Бурханд итгэх тэдний итгэл хүчингүй, тэд зан чанарын өөрчлөлтөд хүрч чадахгүй. Үнэнийг жинхэнээсээ эрэлхийлдэг, Бурханы мэдлэгийг эрж хайдаг, амийг эрэлхийлдэг хүмүүс л Бурханд үнэхээр итгэдэг хүмүүс билээ.

Чам дээр шалгалт ирэхэд тэдгээр шалгалтыг зохицуулахдаа Бурханы ажлыг хэрхэн хэрэглэх вэ? Чи сөрөг байх уу эсвэл хүн дээр хийх Бурханы шалгалт, цэвэршүүлэлтийг эерэг талаас нь ойлгох уу? Чи Бурханы шалгалт, цэвэршүүлэлтээр дамжуулан юуг олж авах вэ? Бурханыг гэх чиний хайр өсөх үү? Цэвэршүүлэлтэд орох үедээ Иовын шалгалтыг хэрэглэж, Бурханы чамд хийдэг ажилд чин сэтгэлээсээ оролцож чадах уу? Иовын шалгалтаар дамжуулан Бурхан хүнийг хэрхэн шалгадгийг чи харж чадах уу? Иовын ажил чамд ямар урам зориг өгч чадах вэ? Цэвэршүүлэлтийнхээ дунд чи Бурханы төлөө гэрчлэлд зогсоход бэлэн байх уу, эсвэл тав тухтай орчинд махан биеийг хангалуун байлгахыг хүсэх үү? Бурханд итгэх итгэлийн талаарх чиний харах өнцөг үнэндээ ямар вэ? Энэ нь үнэхээр махан биеийн төлөө биш, Түүний төлөө байдаг уу? Эрж хайхдаа эрэлхийлдэг зорилт чамд үнэхээр байдаг уу? Чи Бурханаар төгс болгуулахын тулд цэвэршүүлэлт туулахад бэлэн байна уу, эсвэл Бурханаар гэсгээгдэж, хараагдахыг илүүд үзэх үү? Бурханы төлөө гэрчлэл хийх хэрэг явдлын тухайд чи үнэндээ ямар үзэл бодолтой вэ? Бурханы төлөө жинхэнэ гэрчлэл хийх тодорхой орчин нөхцөлд хүмүүс юу хийх ёстой вэ? Чамд хийсэн жинхэнэ ажилдаа бодитой Бурхан маш ихийг илчилсэн байтал яагаад чи үргэлж явах тухай боддог вэ? Бурханд итгэх чиний итгэл Бурханы төлөө байдаг уу? Та нарын ихэнхийнх нь хувьд итгэл бол өөрийн хувийн ашиг тусыг эрэлхийлэхийн төлөө, өөрийнхөө тусын тулд хийдэг тооцооны хэсэг юм. Маш цөөхөн хүн Бурханы төлөө Бурханд итгэдэг; энэ чинь тэрслүү байдал бус уу?

Цэвэршүүлэлтийн ажлын гол зорилго нь хүмүүсийн итгэлийг төгс болгох юм. Эцэст нь юунд хүрэх вэ гэхээр чи явахыг хүссэн ч явж чадахгүй, зарим хүн үлдсэн өчүүхэн найдвараа алдсан байсан ч гэсэн итгэсээр байж чадна, мөн хүмүүс хэтийн төлөвийнхөө төлөө ямар ч найдвар тээхээ болих юм. Зөвхөн энэ үед л Бурханы цэвэршүүлэлт дуусдаг. Амьдрал, үхлийн хооронд эргэлддэг үе шатанд хүн хүрээгүй л байгаа, тэд үхлийг үзээгүй учраас цэвэршүүлэлтийн явц хараахан дуусаагүй байна. Үйлчлэл үзүүлэгчийн шатанд байсан хүмүүс хүртэл дээд зэргээр цэвэршүүлэгдээгүй. Иов дээд зэргийн цэвэршүүлэлтийг туулсан, түүнд итгэж найдах юу ч байгаагүй. Хүмүүс ямар ч найдваргүй, итгэж найдах юу ч байхгүй болох хүртлээ цэвэршүүлэлтийг туулах ёстой—энэ л жинхэнэ цэвэршүүлэлт билээ.

Үйлчлэл үзүүлэгчийн цаг үед зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван байсан бол, Тэр юу ч хийсэн, чиний төлөө гэсэн Түүний хүсэл ямар ч байсан, чи Түүний зохицуулалтыг үргэлж дуулгавартай дагасан бол замын төгсгөлд Бурханы хийсэн бүхнийг чи ойлгох болно. Чи Иовын шалгалтыг туулдаг, мөн нэгэн зэрэг Петрийн шалгалтыг туулдаг. Иовыг турших үед тэр гэрчлэлд зогсож, эцэст нь Ехова түүнд илчлэгдсэн. Гэрчлэлд зогссоны дараа л тэр Бурханы нүүр царайг харах эрхтэй болсон. “Би бузар газар нутгаас нуугдаж, ариун хаанчлалд Өөрийгөө харуулдаг” гэж яагаад хэлдэг вэ? Энэ нь чи ариун байж, гэрчлэлд зогссон үед л Бурханы нүүр царайг харах нэр хүндтэй болж чадна гэсэн үг юм. Хэрэв чи Түүний төлөө гэрчлэлд зогсож чадахгүй бол Түүний нүүр царайг харах нэр хүнд чамд байхгүй. Цэвэршүүлэлттэй тулгарахад ухарч няцан, Бурханы эсрэг гомдол гаргаж, ингэснээрээ Түүний төлөө гэрчлэлд зогсож чадалгүй, Сатаны доог тохуу болбол чи Бурханы илрэлтийг олж харахгүй. Хэрэв чи шалгалтын дунд өөрийн махан биеийг харааж, Бурханы эсрэг гомдоллолгүй, гомдоллож, үгээрээ нүгэл үйлдэлгүйгээр өөрийн махан биеийг жигшиж чадсан Иов шиг байвал гэрчлэлд зогсох болно. Цэвэршүүлэлтийг тодорхой хэмжээгээр туулсан ч Иов шиг хэвээр байж, Бурханы өмнө бүрэн дуулгавартай байж, Түүнээс өөр зүйл шаардахгүй, бас өөрийн үзэлгүй байж чадах аваас Бурхан чамд харагдана. Одоо чамд Бурхан харагддаггүйн учир нь чамд маш олон өөрийн гэсэн үзэл, хувийн алагчлал, хувиа хичээсэн бодол, хувийн шаардлага, махан биеийн ашиг сонирхол байдаг бөгөөд чи Түүний царай төрхийг харахад тэнцэхгүй. Хэрэв чи Бурханыг хардаг байсан бол өөрийн үзлээр Түүнийг хэмжинэ, ингэснээрээ чи Түүнийг загалмайд цовдлох байсан. Чиний үзэлтэй нийцэхгүй олон зүйл чамд тохиолддог боловч чи тэдгээрийг хойш тавьж, тэдгээр зүйлээс Бурханы үйлдлийн талаар мэдлэг олж авч чаддаг бөгөөд цэвэршүүлэлтийн дунд Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээ илчилдэг бол энэ нь гэрчлэлд зогсох билээ. Гэр чинь амар тайван, махан биеийн тав тухад чи дуртай, хэн ч чамайг мөрдөн мөшгөхгүй, чуулган дахь ах эгч нар чинь чамайг дуулгавартай дагадаг бол чи Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээ харуулж чадах уу? Ийм нөхцөл байдал чамайг цэвэршүүлж чадах уу? Цэвэршүүлэлтээр л дамжуулан Бурханыг гэх хайраа харуулж чадна, чиний үзэлтэй нийцдэггүй зүйл тохиолдсоноор л чи төгс болгуулж чадна. Олон эсрэг, сөрөг зүйлийн үйлчлэлээр, мөн Сатаны үйлдэл, буруушаалт, үймээн, мэхлэлт гээд бүх төрлийн илрэлийг хэрэглэснээр Сатаны үзэшгүй муухай царайг Бурхан чамд тодорхой харуулж, ингэснээрээ Сатаныг ялган таних, Сатаныг үзэн ядаж, хаях чадварыг чинь төгс болгодог.

Чиний бүтэлгүйтэл, сул дорой байдлын олон туршлага, сөрөг байдалтай байх үеийг бүгдийг нь Бурханы шалгалт гэж хэлж болно. Учир нь бүх зүйл Бурханаас ирдэг, бүх зүйл, үйл явдал Түүний гарт байдаг. Чиний бүтэлгүйтэх эсэх эсвэл чиний сул дорой байж, бүдрэх эсэх нь бүгд Бурханаас шалтгаалах бөгөөд Бурханы гарт байдаг. Бурханы харах өнцгөөс энэ бол чиний шалгалт, хэрэв чи үүнийг таньж чадахгүй бол энэ нь уруу таталт болох болно. Хүмүүсийн таних ёстой хоёр төрлийн

байдал байдаг: Нэг нь Ариун Сүнснээс ирдэг ба нөгөөгийнх нь магадлалтай эх үүсвэр нь Сатан юм. Нэг нь, Ариун Сүнс чамайг гэрэлтүүлснээр чамд өөрийгөө мэдэх, өөрийгөө жигших, өөртөө харамсах сэтгэл төрж, Бурханыг үнэхээр хайрлах, Түүнийг сэтгэл хангалуун байлгахад зүрх сэтгэлээ зориулах боломж олгодог байр байдал юм. Нөгөө нь чи өөрийгөө мэддэг боловч, сөрөг, сул дорой байдаг байр байдал юм. Энэ байдлыг Бурханы цэвэршүүлэлт, мөн Сатаны уруу таталт ч гэж хэлж болно. Хэрэв чи үүнийг чамайг аврах Бурханы аврал гэж танивал, мөн одоо Түүнд гүнээ өртэй гэдгээ мэдэрвэл, хэрэв одоогоос эхлэн Түүний ачийг хариулахаар хичээж, цаашид ийм доройтолд унахаа боливол, Түүний үгийг идэж, уухад хүчин чармайлт гаргавал, өөрийгөө үргэлж дутуу байна гэж үзэж, хүсэн тэмүүлэх зүрх сэтгэлтэй байвал энэ нь Бурханы шалгалт юм. Зовлон зүдүүр дуусаж, чи дахин нэгэнтээ урагшлах үед Бурхан чамайг хөтөлж, гэрэлтүүлж, гэгээрүүлж, тэжээн тэтгэсээр байх болно. Харин чи үүнийг танихгүй, сөрөг байж, өөрийгөө зүгээр л цөхрөлд оруулж, ийм байдлаар бодвол Сатаны уруу таталт чам дээр ирсэн байх болно. Иов шалгалт туулах үед Бурхан, Сатан хоёр хоорондоо мөрий тавьж байсан бөгөөд Иовыг зовоохыг Бурхан Сатанд зөвшөөрсөн. Хэдийгээр энэ нь Бурханы Иовыг шалгах шалгалт байсан ч гэсэн үнэн хэрэгтээ Сатан түүн дээр ирсэн. Сатаны хувьд тэр Иовыг уруу татаж байсан боловч Иов Бурханы талд байсан. Тийм байгаагүй бол Иов уруу таталтад орох байсан. Хүмүүс уруу таталтад ормогцоо аюулд ордог. Цэвэршүүлэлт туулахыг Бурханы шалгалт гэж хэлж болох боловч хэрэв чи сайн байдалтай биш бол үүнийг Сатаны уруу таталт гэж хэлж болно. Үзэгдэл чамд тодорхой биш бол Сатан чамайг буруутгаж, үзэгдлийг чинь тодорхойгүй болгоно. Чи өөрөө ч мэдэлгүй уруу таталтад автана.

Чи Бурханы ажлыг туулахгүй бол хэзээ ч төгс болгуулж чадахгүй. Туршлагаараа чи мөн жижиг зүйлс рүү орох ёстой. Жишээ нь ямар зүйлс чамайг үзэл болон хэт их сэдэлтэй болгоход хүргэдэг, ямар төрлийн тохирох хэрэгжүүлэлтээр эдгээр асуудалд хандах ёстой болдог вэ? Хэрэв чи Бурханы ажлыг туулж чаддаг бол энэ нь чамд биеийн хэмжээ байна гэсэн үг юм. Хэрэв чамд эрч хүч байгаа юм шиг л харагддаг бол энэ нь жинхэнэ биеийн хэмжээ биш бөгөөд чи баттай зогсож огт чадахгүй байх болно. Чи Бурханы ажлыг туулж чаддаг, үүнийг хэзээ ч хаана ч туулж, тунгаан бодож чаддаг, хоньчдыг орхиж, Бурханыг түшиж бие даан амьдарч чаддаг, Бурханы бодит үйлдлийг харж чаддаг болсон цагт л Бурханы хүсэл биелэх болно. Яг одоо ихэнх хүн хэрхэн туршлагажихаа мэддэггүй бөгөөд тэд асуудалтай тулгарах үедээ хэрхэн зохицуулахаа мэддэггүй; тэд Бурханы ажлыг туулах чадваргүй, сүнслэг амьдралаар амьдарч чаддаггүй. Чи Бурханы үгийг авч, бодитой амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.

Заримдаа Бурхан чамд тодорхой нэг төрлийн мэдрэмжийг буюу дотоод баяр жаргал болон Бурханд ойр байдлаа алдахад хүргэж, харанхуйд живүүлдэг тийм мэдрэмжийг өгдөг. Энэ бол цэвэршүүлэлтийн нэг төрөл юм. Чи аливаа зүйлийг хийх болгондоо бүтэлгүйтэх юм уу эсвэл хана мөргөдөг. Энэ бол Бурханы

сахилгажуулалт юм. Заримдаа чамайг Бурханд дуулгаваргүй, тэрслүү зүйл хийхэд хэн ч мэдэхгүй байж болох боловч Бурхан мэддэг. Тэр чамайг зүгээр өнгөрөөхгүй, сахилгажуулах болно. Ариун Сүнсний ажил маш нарийн байдаг. Тэр хүмүүсийн үг үйлдэл, үйл хөдлөл, бодол санаа бүрийг сайтар ажиглаж, ингэснээр хүмүүс эдгээр зүйлийн талаар дотоод мэдлэг ойлголт олж авдаг. Чи ямар нэг зүйлийг хийгээд бүтэлгүй болж, дахин ямар нэг зүйл хийгээд бас л бүтэлгүйтэж, аажмаар чи Ариун Сүнсний ажлыг ойлгож авах болно. Олон удаагийн сахилгажуулалтаар дамжуулан чи Бурханы хүсэлд нийцүүлэхийн тулд юу хийх ёстой, Түүний хүсэлд юу нийцдэггүйг мэдэх болно. Эцэст нь чамайг дотроос чинь чиглүүлэх Ариун Сүнсний удирдамжид чи зөв хариу өгөх болно. Заримдаа чи тэрслүү байх бөгөөд Бурхан чамайг дотроос чинь зэмлэх болно. Энэ бүхэн Бурханы сахилгажуулалтаас ирдэг. Хэрэв чи Бурханы үгийг нандигнадаггүй бол, Түүний ажилд хайнга хандвал Тэр чамайг хайхрахаа болино. Бурханы үгийг хэдий чинээ нухацтай авч үзнэ, Тэр чамайг төдий чинээ гэгээрүүлэх болно. Яг одоо чуулганд будилж, төөрөлдсөн итгэлтэй зарим хүн байгаа бөгөөд тэд маш олон зохисгүй зүйл хийж, сахилга батгүй үйлдэл гаргадаг учраас Ариун Сүнсний ажлыг тэднээс тодорхой харах боломжгүй байдаг. Зарим хүн мөнгө олохын тулд үүргээ умартаж, сахилгажуулагдалгүйгээр гарч бизнес хийдэг; ийм хүн илүү их аюулд ордог. Одоогоор тэдэнд Ариун Сүнсний ажил байхгүй төдийгүй ирээдүйд ч тэднийг төгс болгоход хэцүү байх болно. Олон хүнээс Ариун Сүнсний ажил, Бурханы сахилгажуулалтыг харах боломжгүй байдаг. Тэд бол Бурханы хүслийн талаар тодорхой ойлгоогүй, Түүний ажлыг мэддэггүй хүмүүс юм. Цэвэршүүлэлтийн дунд бат бөх зогсож чаддаг, Бурхан юу ч хийсэн Түүнийг дагадаг, ядаж л явахгүй байж чаддаг эсвэл Петрийн хүрсэн зүйлийн 0,1%-д нь хүрч чаддаг хүмүүс дажгүй явж байгаа боловч Бурханы тэднийг ашиглах тухайд гэвэл тэдэнд ямар ч үнэ цэн байхгүй. Олон хүн юмыг хурдан ойлгож, Бурханыг үнэхээр хайрлаж, Петрийн түвшнийг давж чаддаг бөгөөд Бурхан төгс болгох ажлаа тэдэн дээр хийдэг. Ийм хүмүүст сахилгажуулалт, гэгээрэл ирдэг бөгөөд Бурханы хүсэлтэй нийцэхгүй ямар нэг зүйл тэдэнд байвал тэд даруйхан хаяж чаддаг. Ийм хүмүүс бол алт, мөнгө, үнэт чулуунууд бөгөөд тэдний үнэ цэн хамгийн өндөр! Бурхан олон төрлийн ажил хийсэн боловч чи элс, чулуу мэт хэвээр байх юм бол ямар ч үнэ цэнгүй!

Агуу улаан лууны улс оронд хийсэн Бурханы ажил гайхамшигтай бөгөөд ойлгохын аргагүй билээ. Тэр нэг бүлэг хүнийг төгс болгож, бусдыг нь таягдан хаяна, учир нь чуулганд бүхий л төрлийн хүн байдаг—үнэнийг хайрладаг хүмүүс байна, хайрладаггүй хүмүүс байна; Бурханы ажлыг туулдаг хүмүүс байна, туулдаггүй хүмүүс байна; үүргээ биелүүлдэг хүмүүс байна, биелүүлдэггүй хүмүүс байна; Бурханыг гэрчилдэг хүмүүс байна, гэрчилдэггүй хүмүүс байна, мөн тэдгээрийн тодорхой хэсэг нь үл итгэгчид, ёрын муу хүмүүс бөгөөд тэднийг гарцаагүй таягдан хаяна. Хэрэв чи Бурханы ажлыг тодорхой мэддэггүй бол сөрөг байх болно; учир нь хүмүүсийн цөөнхөөс л Бурханы ажлыг харж болно. Энэ цаг үед хэн Бурханыг

үнэхээр хайрладаг, хэн хайрладаггүй нь тодорхой болох болно. Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүст Ариун Сүнсний ажил байдаг байхад Түүнийг үнэхээр хайрладаггүй хүмүүс Түүний ажлын алхам бүрийн явцад илчлэгдэх болно. Тэд таягдан хаягдах хүмүүс болно. Байлдан дагуулалтын ажлын явцад эдгээр хүн илчлэгдэх бөгөөд тэд бол төгс болгуулах үнэ цэнгүй хүмүүс билээ. Төгс болгуулсан хүмүүс бүгд Бурханаар авхуулсан бөгөөд Петрийн хайрладаг байсан шиг Бурханыг хайрлах чадвартай байдаг. Байлдан дагуулагдсан хүмүүст өөрөө үүссэн хайр биш харин идэвхгүй хайр л байдаг бөгөөд тэд албадлагаар Бурханыг хайрладаг. Өөрөө үүсдэг хайр нь бодит туршлагаар олж авсан ойлголтоор дамжин бий болдог. Энэ хайр хүний зүрх сэтгэлийг эзэмдэж, сайн дурааараа Бурханы төлөө зүтгэхэд хүргэдэг; Бурханы үг тэдний үндэс суурь болж, тэд Бурханы төлөө зовж зүдэрч чаддаг. Мэдээж эдгээр нь Бурханаар төгс болгуулсан хүнд байдаг зүйлс юм. Хэрэв чи байлдан дагуулагдахыг л эрэлхийлдэг бол Бурханы төлөө гэрчлэл хийж чадахгүй; Бурхан хүмүүсийг байлдан дагуулах замаар л авралын зорилгодоо хүрдэг бол үйлчлэл үзүүлэгчдийн алхам ажлыг дуусгах байсан. Гэхдээ Бурханы эцсийн зорилго нь хүмүүсийг байлдан дагуулах биш, харин хүмүүсийг төгс болгох юм. Тиймээс энэ үе шатыг байлдан дагуулалтын ажил гэж хэлэхийн оронд төгс болгох, таягдан хаях ажил гэж хэл. Зарим хүн бүрэн байлдан дагуулагдаагүй бөгөөд тэднийг байлдан дагуулах явцад бүлэг хүн төгс болох болно. Энэ хоёр хэсэг ажлыг нэгэн зэрэг хэрэгжүүлдэг. Ийм урт хугацааны ажлын туршид хүртэл хүмүүс орхиж яваагүй бөгөөд энэ нь байлдан дагуулалт зорилгодоо хүрсэн гэдгийг харуулдаг—энэ бол байлдан дагуулагдсаны баримт юм. Цэвэршүүлэлт нь байлдан дагуулагдахын төлөө биш, харин төгс болгуулахын төлөө байдаг. Цэвэршүүлэлтгүйгээр хүмүүсийг төгс болгох боломжгүй. Тиймээс цэвэршүүлэлт үнэхээр үнэ цэнтэй! Өнөөдөр нэг бүлэг хүмүүс төгс болгуулж, авхуулагдаж байна. Өмнө нь дурдагдсан арван ерөөл нь бүгд төгс болгуулсан хүмүүст чиглэсэн юм. Газар дээрх дүр төрхөө өөрчлөх тухай зүйл нь бүгд төгс болгуулсан хүмүүст чиглэдэг. Төгс болгуулаагүй хүмүүс Бурханы амлалтыг хүлээж авах шаардлага хангадаггүй.

ЗОВЛОНТ ШАЛГАЛТЫГ ТУУЛСНААР Л БУРХАНЫ ХАЙР ТАТАМ БАЙДЛЫГ МЭДЭЖ БОЛНО

Өнөөдөр чи Бурханыг яг хэр их хайрладаг вэ? Бурханы чамд хийсэн бүхний талаар яг хэр ихийг мэддэг вэ? Эдгээр нь чиний сурах ёстой зүйлс юм. Бурхан газар дээр ирээд хүнд хийсэн, хүнд харуулсан бүхэн нь хүнээр Өөрийгөө хайрлуулж, Өөрийгөө мэдүүлэхийн төлөө байдаг. Хүн Бурханы төлөө зовж, өдий хүрч чадсан нь нэг талаар Бурханы хайраас, нөгөө талаар Бурханы авралаас болдог; түүнчлэн энэ нь хүний дотор Бурханы хийдэг шүүлт, гэсгээлтийн ажлаас болдог. Хэрэв та

нарт Бурханы шүүлт, гэсгээлт, шалгалт байхгүй бол, хэрэв Бурхан та нарыг зовоогоогүй бол ний нуугүй хэлэхэд, та нар Бурханыг үнэхээр хайрладаггүй юм байна. Хүний доторх Бурханы ажил их байх тусам, хүний зовлон их байх тусам Бурханы ажил хэчнээн утга учиртай нь төдий чинээ илэрхий байдаг бөгөөд хүний зүрх сэтгэл Бурханыг төдий чинээ жинхэнээсээ хайрлаж чаддаг. Чи Бурханыг хэрхэн хайрлаж сурах вэ? Тарчлаан, цэвэршүүлэлтгүйгээр, зовлонт шалгалтгүйгээр, мөн түүнчлэн Бурхан хүнд нигүүлсэл, хайр, өршөөлийг л өгдөг байсан бол чи Бурханыг үнэхээр хайрлаж чадах хэмжээнд хүрэх байсан уу? Бурханы шалгалтын үеэр хүн нэг талаар, өөрийнхөө дутагдлыг мэдэж авч, өчүүхэн, олиггүй, дорд гэдгээ болон өөрт нь юу ч байхгүй, өөрөө юу ч биш гэдгийг хардаг; нөгөө талаар, шалгалтынхаа үеэр Бурхан хүнд зориулан өөр өөр орчин бүтээж, хүнийг Бурханы хайр татам байдлыг улам илүү мэдрэх чадвартай болгодог. Өвдөлт шаналал асар их, заримдаа гэтлэхийн аргагүй байдаг ч—бүр няц дарам гаслангийн хэмжээнд хүрдэг ч—үүнийг туулаад хүн өөрийнх нь доторх Бурханы ажил хэчнээн хайр татам болохыг хардаг бөгөөд энэ суурин дээр л Бурханыг гэх жинхэнэ хайр хүний дотор төрдөг. Өнөөдөр хүн, гагцхүү Бурханы нигүүлсэл, хайр, өршөөлтэйгээр өөрийгөө үнэхээр мэдэж чадахгүй, хүний мөн чанарыг мэдэж бүр ч чадахгүй гэдгийг хардаг. Бурханы цэвэршүүлэлт, шүүлтийн аль алинаар л дамжуулан, цэвэршүүлэлтийн үйл явцын үеэр л хүн дутагдлаа мэдэж, өөрт нь юу ч байхгүй гэдгийг мэдэж чадна. Тиймээс Бурханыг гэх хүний хайр Бурханы цэвэршүүлэлт, шүүлтийн суурин дээр бий болдог. Хэрэв чи зөвхөн Бурханы нигүүлслийг эдэлж, амар тайван гэр бүлтэй, эсвэл материаллаг ерөөлтэй байгаа бол Бурханыг хараахан олж аваагүй бөгөөд Бурханд итгэх итгэлийг чинь амжилттай гэж үзэж болохгүй. Бурхан нигүүлслийн ажлын нэг үе шатыг аль хэдийн махбодоор гүйцэтгэчихсэн, бас хүнд материаллаг ерөөл аль хэдийн хүртээчихсэн, гэхдээ хүн гагцхүү нигүүлсэл, хайр, өршөөлөөр төгс болгуулж чадахгүй. Хүмүүс туршлагаараа Бурханы хайрын заримыг мэдэрч, Бурханы хайр, өршөөлийг хардаг ч үүнийг хэсэгхэн хугацаанд туулаад, Бурханы нигүүлсэл, хайр, өршөөл нь хүнийг төгс болгож чадахгүй, хүний доторх завхарсан зүйлийг илчилж чадахгүй, хүнийг завхарсан зан чанараас нь ангижруулж чадахгүй, хайр, итгэлийг нь төгс болгож чадахгүй гэдгийг хардаг. Бурханы нигүүлслийн ажил нь нэг үе шатны ажил байсан бөгөөд хүн Бурханы нигүүлслийг эдэлснээр Бурханыг мэдэж авч чадахгүй.

Бурхан ямар арга барилаар дамжуулан хүнийг төгс болгодог вэ? Өөрийнхөө зөвт зан чанараар үүнийг гүйцэтгэдэг. Бурханы зан чанар нь үндсэндээ зөвт байдал, уур хилэн, сүр жавхлан, шүүлт, хараалаас бүрддэг бөгөөд Тэрээр хүнийг үндсэндээ шүүлтээрээ дамжуулан төгс болгодог. Зарим хүн ойлгодоггүй бөгөөд Бурхан яагаад хүнийг шүүлт, хараалаар л төгс болгож чаддаг юм бэ гэж асуудаг. Тэд: “Бурхан хүнийг хараавал хүн үхэхгүй гэж үү? Хэрэв Бурхан хүнийг шүүвэл хүн яллагдахгүй гэж үү? Тэгвэл түүнийг яаж бас төгс болгож чадах юм бэ?” гэцгээдэг. Энэ бол Бурханы ажлыг мэддэггүй хүмүүсийн үг юм. Бурхан хүний дуулгаваргүй

занг харааж, хүний нүглийг шүүдэг. Тэрээр хатуу ширүүнээр, хайр найргүйгээр ярьдаг хэдий ч хүний дотор буй бүхнийг илчилж, эдгээр хатуу үгээр хүний доторх гол зүйлийг ил болгож, ийм шүүлтээр дамжуулан махан биеийн мөн чанарын талаар хүнд гүн гүнзгий мэдлэг өгч, улмаар хүн Бурханы өмнө дуулгавартай байдаг. Хүний махан бие нүгэл болон Сатанд харьяалагддаг, энэ нь дуулгаваргүй бөгөөд Бурханы гэсгээлтийн бай юм. Тиймээс хүнд өөрийгөө мэдэх боломжийг олгохын тулд Бурханы шүүлтийн үг түүн дээр буух ёстой ба төрөл бүрийн цэвэршүүлэлт хэрэглэх ёстой; зөвхөн тэр үед л Бурханы ажил үр нөлөөтэй болж чадна.

Бурханы хэлсэн үгээс үзэхэд хүний махан биеийг Тэр аль хэдийн ялласан нь харагддаг. Тэгэхээр эдгээр үг нь хараалын үг биш гэж үү? Бурханы хэлсэн үг хүний үнэн царайг илчилж, тийм илчлэлээр дамжуулан хүнийг шүүдэг бөгөөд Бурханы хүслийг хангаж чадахгүй гэдгээ мэдэх үедээ хүн дотроо гашуудан харуусаж, Бурханд маш их өртэйгөө, Бурханы хүсэлд хүрч чадахгүй гэдгээ мэдэрдэг. Ариун Сүнс чамайг дотроос чинь сахилгажуулах үе байдаг ба энэ сахилгажуулалт Бурханы шүүлтээс гардаг; Бурхан чамайг зэмлэж, чамаас царайгаа нуун, чамайг үл хайхарч, дотор чинь ажиллахгүй байж, чамайг цэвэршүүлэхийн тулд чимээгүйхэн гэсгээх үе бий. Хүний доторх Бурханы ажил нь үндсэндээ Өөрийн зөвт зан чанарыг ил болгохын төлөө байдаг. Эцэстээ хүн Бурханы өмнө ямар гэрчлэл хийдэг вэ? Бурхан бол зөвт Бурхан, Түүний зан чанар бол зөвт байдал, уур хилэн, гэсгээлт, шүүлт юм гэдгийг хүн гэрчилдэг; хүн Бурханы зөвт зан чанарыг гэрчилдэг. Хүнийг төгс болгохын тулд Бурхан шүүлтээ хэрэглэдэг, Тэр хүнийг хайрлаж, аварсан—гэхдээ Түүний хайр хэр ихийг агуулдаг вэ? Тэнд шүүлт, сүр жавхлан, уур хилэн, хараал бий. Урьд нь Бурхан хүнийг хараасан хэдий ч ёроолгүй нүхэнд бүрмөсөн хаяагүй, харин хүний итгэлийг цэвэршүүлэхийн тулд тэр аргыг ашигласан; хүнийг Тэр үхүүлээгүй, харин хүнийг төгс болгохын төлөө үйлдсэн юм. Махан биеийн мөн чанар Сатаных байдаг—Бурхан үүнийг яг зөв хэлсэн—гэхдээ Бурханы гүйцэтгэсэн баримт хэлсэн үгийнх нь дагуу гүйцэлддэггүй. Тэр Өөрийгөө хайрлуулах гэж, мөн махан биеийн мөн чанарыг мэдүүлэх гэж чамайг хараадаг; чамайг сэрээж, чамд буй дутагдлыг ухааруулж, хүний туйлын үнэ цэнгүй байдлыг мэдүүлэх гэсэндээ Тэр чамайг гэсгээдэг. Тиймээс Бурханы хараал, Түүний шүүлт, Түүний сүр жавхлан, уур хилэн—бүгд хүнийг төгс болгохын төлөө байдаг билээ. Өнөөдөр Бурханы хийдэг бүхэн, мөн та нарын дотор Түүний ил болгодог зөвт зан чанар—энэ бүхэн нь хүнийг төгс болгохын төлөө байдаг. Энэ нь Бурханы хайр юм.

Хүний уламжлалт үзлээр, Бурханы хайр бол Түүний нигүүлсэл, өршөөл, хүний сул талыг өрөвдөх хайр энэрэл юм гэж хүн боддог. Хэдий эдгээр зүйл ч бас Бурханы хайр мөн боловч хэтэрхий өрөөсгөл бөгөөд хүнийг төгс болгодог Бурханы үндсэн арга барил биш. Зарим хүн өвчнөөс болоод Бурханд итгэж эхэлсэн. Энэ өвчин бол чамд зориулсан Бурханы нигүүлсэл; үүнгүйгээр чи Бурханд итгэхгүй байх байсан бөгөөд хэрвээ чи Бурханд итгээгүй бол өдий хүрч чадахгүй байх байсан—тиймээс энэ нигүүлсэл ч гэсэн Бурханы хайр юм. Есүст итгэдэг байсан цаг

үед хүмүүс үнэнийг ойлгоогүй учраас Бурханы дургүйг хүргэх юм их хийсэн, гэвч Бурханд хайр, өршөөл байдаг бөгөөд Тэрээр хүнийг өдий хүргэсэн, мөн хүн юу ч ойлгодоггүй хэдий ч Өөрийг нь дагахыг Бурхан хүнд зөвшөөрдгөөс гадна хүнийг эдүгээ хүртэл удирдан хөтөлсөн. Энэ Бурханы хайр биш гэж үү? Бурханы зан чанараас харагддаг зүйл бол Бурханы хайр юм—энэ бол туйлын үнэн! Чуулганыг байгуулах явдал оргилдоо хүрэх үед Бурхан үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхмыг хийж, хүнийг ёроолгүй нүхэнд хаясан. Үйлчлэл үзүүлэгчдийн үеийн үгс бүгд махан биеийг чинь хараах, завхарсан сатанлаг зан чанарыг чинь хараах, мөн Бурханы хүслийг хангалуун байлгадаггүй зүйлсийг чинь хараах хараал байлаа. Тэрхүү алхамд Бурханы хийсэн ажил сүр жавхлан мэт харагдаж, үүний дараахан Бурхан гэсгээлтийн ажлын алхмыг гүйцэтгээд, үхлийн шалгалт эхэлжээ. Ийм ажлаас хүн Бурханы уур хилэн, сүр жавхлан, шүүлт, гэсгээлтийг харахын зэрэгцээ бас Бурханы нигүүлсэл, хайр, өршөөлийг харсан юм; Бурханы хийсэн бүхэн, Түүний зан чанар болж харагдсан бүхэн нь хүнийг гэх Бурханы хайр байсан бөгөөд Бурханы хийсэн бүхэн хүний хэрэгцээг хангаж чадсан. Хүнийг төгс болгохын тулд Тэр үүнийг хийсэн ба биеийнх нь хэмжээний дагуу хүнийг хангажээ. Бурхан үүнийг хийгээгүй бол хүн Бурханы өмнө ирж чадахгүй, Бурханы үнэн нүүр царайг мэдэх аргагүй байх байлаа. Хүн анх Бурханд итгэж эхэлсэн цагаас өнөөг хүртэл Бурхан хүнийг биеийн хэмжээнд нь тааруулан зугуухан хангаж байсан ба ингэснээр хүн дотроо Бурханыг аажмаар мэдэж авчээ. Өнөөдөр л хүн Бурханы шүүлт хэчнээн гайхалтайг ухаарч байна. Үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхам нь бүтээлийн цаг үеэс өнөөг хүртэлх хараах ажлын анхны тохиолдол байв. Хүн ёроолгүй нүх рүү хараагдсан. Хэрвээ Бурхан тэгээгүй бол хүн өнөөдөр Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй болохгүй байх байлаа; Бурханы хараалаар л дамжуулан хүн Бурханы зан чанартай албан ёсоор тулгарсан юм. Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтаар дамжуулан хүн илчлэгдсэн. Тэрээр өөрийнх нь үнэнч зан хүлээн зөвшөөрөхийн аргагүй, биеийн хэмжээ нь дэндүү жаахан, Бурханы хүслийг хангах чадваргүй, бас Бурханыг цаг үргэлж хангалуун байлгана гэж хэлдэг нь хоосон үгээс цаашгүй гэдгийг харжээ. Үйлчлэл үзүүлэгчдийн ажлын алхамд Бурхан хүнийг хараасан хэдий ч одоо эргээд харахад Бурханы ажлын тэрхүү алхам гайхалтай байлаа: Энэ нь хүний хувьд агуу эргэлтийн цэг болж, түүний амь зан чанарт асар их өөрчлөлт гаргажээ. Үйлчлэл үзүүлэгчдийн цаг үеэс өмнө хүн амийн эрэл хайгуулын талаар, Бурханд итгэх нь юу гэсэн үг болох талаар, эсвэл Бурханы ажлын мэргэн ухааны талаар юу ч ойлгоогүй, мөн Бурханы ажил хүнийг туршиж чадна гэдгийг ч ойлгоогүй. Үйлчлэл үзүүлэгчдийн цаг үеэс өнөөдрийг хүртэлх Бурханы ажил хэчнээн гайхалтай болохыг, хүний ухаан хүрэмгүй гэдгийг олж хардаг. Хүн толгойгоо ажиллуулаад ч Бурхан хэрхэн ажилладгийг төсөөлж чадахгүй гэдгээ харж, түүнчлэн өөрийнх нь биеийн хэмжээ үнэхээр өчүүхэн ба өөрт нь дуулгаваргүй зүйл хэтэрхий их байдгийг хардаг. Бурхан хүнийг хараах үед энэ нь үр дүнд хүрэхийн төлөө байсан бөгөөд Тэр хүнийг үхүүлээгүй юм. Хэдийгээр Тэр хүнийг хараасан ч үгээр л үүнийгээ хийсэн бөгөөд

Түүний хараал үнэндээ хүнд тусаагүй, учир нь Бурханы хараасан зүйл хүний дуулгаваргүй байдал байсан тул Түүний хараалын үг ч бас хүнийг төгс болгохын төлөө хэлэгдсэн. Бурхан хүнийг шүүсэн ч бай, хараасан ч бай, аль аль нь хүнийг төгс болгодог: Хоёулаа хүний доторх ариун бус зүйлийг төгс болгохын төлөө хийгддэг. Энэ аргаар дамжуулан хүн цэвэршүүлэгдэж, хүний дотор дутагдаж байгаа зүйл Түүний үг, ажлаар дамжуулан төгс болдог. Бурханы ажлын алхам бүр—хатуу ширүүн үг ч бай, шүүлт ч бай, эсвэл гэсгээлт ч бай—хүнийг төгс болгодог бөгөөд туйлын зохистой байдаг. Эрин үеүдийн туршид Бурхан ийм ажил хэзээ ч хийж байгаагүй; өнөөдөр Тэр та нарын дотор ажилладаг болохоор та нар Түүний мэргэн ухааныг ойлгодог. Та нар дотроо жаахан өвдөж шаналсан ч зүрх сэтгэл чинь тууштай, амар амгалан байгаа; Бурханы ажлын энэ үе шатыг эдлэх чадвартай байгаа нь та нарын ерөөл билээ. Ирээдүйд юу олж авч чадах чинь хамаагүй, өнөөдөр та нарын дотор Бурханы хийсэн ажил бүхэлдээ хайр гэдгийг л та нар хардаг. Хэрвээ хүн Бурханы шүүлт, цэвэршүүлэлтийг туулдаггүй бол түүний үйлдэл, урам зориг үргэлж өнгөцхөн түвшинд үлдэж, зан чанар нь үргэлж өөрчлөгдөөгүй хэвээр үлдэнэ. Үүнийг Бурханаар авхуулсанд тооцдог уу? Эдүгээ хүний дотор биеэ тоосон, ихэрхүү зан ихээхэн байсаар байгаа боловч хүний зан чанар урьдынхаасаа хавьгүй илүү тогтвортой байдаг. Бурхан чамтай харьцдаг нь чамайг аврахын төлөө байдаг бөгөөд чи тухайн үед хэсэг шаналж магадгүй боловч зан чанарт чинь өөрчлөлт гарах өдөр ирнэ. Тэр үед чи эргэж хараад, Бурханы ажил хэчнээн ухаалаг болохыг ойлгоно, тэр үед л чи Бурханы хүслийг үнэхээр ойлгож чадна. Өнөөдөр Бурханы хүслийг ойлгодог гэж хэлдэг зарим хүн байдаг боловч тэр нь дэндүү бодитой бус юм. Үнэн хэрэгтээ тэд худал ярьж байна, яагаад гэвэл, Бурханы хүсэл хүнийг аврахын төлөө байдаг уу, эсвэл хараахын төлөө байдаг уу гэдгийг тэд одоогоор хараахан ойлгоогүй байгаа. Чи одоо үүнийг тодорхой харж чадахгүй байж болох ч Бурхан алдрыг олж авсан өдөр ирснийг харах үе ирж, Бурханыг хайрлах нь хэчнээн утга учиртайг харна, ингэснээр чи хүний амьдралыг мэдэж авч, махан бие чинь Бурханыг хайрлах ертөнцөд амьдарч, сүнс чинь эрх чөлөөтэй болж, амьдрал чинь баяр хөөрөөр дүүрч, чи үргэлж Бурханд ойр байж, үргэлж Бурхан руу харан найдах болно. Тэр цагт чи өнөөдрийн Бурханы ажил хэчнээн үнэ цэнтэйг лавтайяа мэднэ.

Өнөөдөр ихэнх хүмүүст тийм мэдлэг байдаггүй. Тэд зовлон үнэ цэнгүй, дэлхий ертөнц өөрсдийг нь хаясан, ар гэрийнх нь амьдрал төвөгтэй, өөрсдийг нь Бурхан хайрладаггүй, хэтийн ирээдүй нь бүрхэг гэж итгэдэг. Зарим хүний зовлон дээд цэгтээ хүрэхэд тэдний бодол үхэл рүү ханддаг. Энэ бол Бурханыг гэх жинхэнэ хайр биш; тийм хүмүүс бол хулчгарууд, тэд ямар ч хатуужилгүй, сул дорой, хүчин мөхөс! Хүн Өөрийг нь хайрлаасай хэмээн Бурхан хүсэмжилдэг, гэвч хүн Түүнийг хайрлах тусам хүний зовлон улам ихэсдэг бөгөөд хүн Түүнийг хайрлах тусам хүний шалгалт улам ихэсдэг. Хэрвээ чи Түүнийг хайрлавал төрөл бүрийн зовлон чамайг нөмөрнө, хэрвээ хайрлахгүй бол магадгүй бүх зүйл төвөггүй явагдаж, эргэн тойрны чинь бүх

юм амар жимэр болно. Бурханыг хайрлах үедээ чи, эргэн тойрны чинь ихэнх зүйл даван туулшгүй гэдгийг, бас биеийн хэмжээ чинь дэндүү жаахан учраас цэвэршүүлэгдэнэ гэдгээ мэдэрнэ; түүнчлэн, чи Бурханыг хангалуун байлгах чадваргүй байх бөгөөд Бурханы хүсэл хэтэрхий өндөр дээд, хүн хүрэхийн аргагүй гэдгийг үргэлж мэдэрнэ. Энэ бүхнээс болж чи цэвэршүүлэгдэнэ—чиний дотор ихээхэн сул тал байдаг, мөн Бурханы хүслийг хангах чадваргүй зүйл их байдаг учраас чи дотроо цэвэршүүлэгдэнэ. Гэсэн ч цэвэршүүлэлтээр л дамжуулан ариусгалтад хүрдэг гэдгийг та нар тодорхой харах ёстой. Тиймээс эцсийн энэ өдрүүдэд та нар Бурханд гэрчлэл хийх ёстой. Зовлон чинь хэчнээн их байх нь хамаагүй, та нар бүр эцсийг нь хүртэл алхах ёстой, эцсийн амьсгалаа авч байхдаа ч Бурханд үнэнч байж, Бурханы зохицуулалтад захирагдсаар байх ёстой; энэ нь л Бурханыг үнэхээр хайрлаж байгаа хэрэг бөгөөд энэ нь л хүчтэй, цангинасан гэрчлэл юм. Сатанд уруу татагдах үедээ чи: “Миний зүрх сэтгэл Бурханд харьяалагддаг, Бурхан намайг аль хэдийн олж авсан. Би чамайг хангалуун байлгаж чадахгүй—би Бурханыг хангалуун байлгахын төлөө бүхнээ зориулах ёстой” гэж хэлэх хэрэгтэй. Чи Бурханыг хангалуун байлгах тусам Бурхан чамайг улам их ерөөж, Бурханыг гэх хайр чинь төдий чинээ хүчтэй байдаг; иймээс чи бас итгэлтэй, шийдвэртэй байж, Бурханыг хайрлаж өнгөрүүлсэн амьдралаас илүү үнэ цэнтэй, ач холбогдолтой юу ч үгүй гэдгийг мэдэрнэ. Хүн Бурханыг хайрлаж байж л уй гашуугүй байдаг гэж хэлж болно. Махан бие чинь сульдаж, олон бодит зовлонд ороогдох үе байдаг боловч тийм үеүдэд чи Бурханд үнэхээр найдах бөгөөд сүнсэн дотроо тайтгарч, итгэлтэй байж, түшиглэх ямар нэгэн зүйл чамд байгааг мэдэрнэ. Ийм маягаар чи олон орчин нөхцөлийг даван гарч чадах тул амсдаг зовлон шаналлаасаа болоод Бурханы талаар гомдоллохгүй. Харин дуулж, бүжиглэж, залбирч, цугларч, нөхөрлөж, Бурханыг бодохыг хүсэх бөгөөд эргэн тойронд чинь Бурханы зохицуулдаг бүх хүн, хэрэг явдал, зүйл тохиромжтой гэдгийг мэдэрнэ. Чи Бурханыг хайрладаггүй бол харсан бүхэн чинь чамд яршигтай санагдаж, нүдэнд чинь юу ч аятайхан харагдахгүй; сүнсээрээ чи чөлөөтэй бус, харин сэтгэлийн дарамттай байх ба зүрх сэтгэл чинь үргэлж Бурханы талаар гомдоллоно, мөн маш их тарчлаан амсаж байгаа чинь тун шударга бус юм гэж чамд үргэлж санагдана. Хэрвээ чи аз жаргалын хойноос хөөцөлддөггүй, харин Бурханыг хангалуун байлгахын тулд, Сатанаар буруутгагдахгүйн төлөө эрэлхийлдэг бол ийм эрэл хайгуул чамд Бурханыг хайрлах асар их хүч өгнө. Хүн Бурханы хэлсэн бүхнийг хэрэгжүүлэх чадвартай, бас хийдэг бүхэн нь Бурханыг хангалуун байлгах чадвартай—бодит байдлыг эзэмших гэдэг нь энэ юм. Бурханыг хангалуун байлгахаар эрэлхийлнэ гэдэг нь Бурханы үгийг хэрэгжүүлэхийн тулд Бурханыг гэх хайраа ашиглах явдал юм; цаг хугацаанаас үл хамааран—бусад хүн хүч чадалгүй байлаа ч гэсэн—чиний дотор Бурханыг хайрладаг, Бурханыг гүнээ эгээрэн хүсэж, Бурханыг үгүйлдэг зүрх сэтгэл байсаар байгаа. Энэ бол жинхэнэ биеийн хэмжээ юм. Чиний биеийн хэмжээ яг хэр том болох нь Бурханыг хэр их хайрладгаас чинь, туршигдах үедээ бат зогсож чаддаг эсэхээс

чинь, тодорхой орчин нөхцөл тохиолдоход сул дорой болдог эсэхээс чинь, мөн ах, эгч нар чинь чамайг голох үед байр сууриндаа бат зогсож чаддаг эсэхээс чинь хамаардаг; Бурханыг гэх хайр чинь яг ямархуу болохыг бодит баримтууд харуулна. Бурхан хүнд үнэхээр хайртай гэдгийг Бурханы олон ажлаас харж болно, гэхдээ хүний сүнсний нүд хараахан бүрэн нээгдээгүй бөгөөд тэрээр Бурханы ажил болон хүслийн ихээхнийг тодорхой харж чаддаггүй, Бурханы хайр татам олон зүйлийг ч тодорхой харж чаддаггүй; хүнд Бурханыг гэх жинхэнэ хайр дэндүү бага байдаг. Чи энэ бүх хугацаанд Бурханд итгэсэн ба өнөөдөр Бурхан зугтах бүх арга замыг чинь хаасан. Үнэнийг хэлэхэд, чи зөв замыг буюу Бурханы хатуу шүүлт, дээд авралаар чамайг удирдан хөтөлсөөр ирсэн зөв замыг сонгохоос өөр аргагүй. Бэрхшээл, цэвэршүүлэлт туулсны дараа л хүн Бурхан хайр татам гэдгийг мэддэг. Өнөөдрийг хүртэл туулсан болохоор хүн Бурханы хайр татам байдлын нэг хэсгийг мэдэж авсан гэж хэлж болно, гэхдээ хүн маш дутуу дулимаг учраас энэ нь бас л хангалтгүй. Хүн Бурханы гайхалтай ажлыг, мөн Бурханы зохицуулсан зовлонгийн бүх цэвэршүүлэлтийг илүү их туулах ёстой. Тэр үед л хүний амь зан чанар өөрчлөгдөж чадна.

БУРХАНЫГ ХАЙРЛАХ НЬ Л ҮНЭХЭЭР БУРХАНД ИТГЭЖ БУЙ ХЭРЭГ

Өнөөдөр та нар Бурханыг мэдэж, хайрлахаар эрж хайхдаа нэг талаар зовлон бэрхшээл, цэвэршүүлэлт туулж, нөгөө талаар төлөөс төлөх ёстой. Бурханыг хайрлах хичээлээс илүү гүн гүнзгий хичээл гэж үгүй бөгөөд насан туршдаа итгэхдээ хүмүүсийн авдаг сургамж нь Бурханыг хэрхэн хайрлах тухай байдаг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи Бурханд итгэдэг бол Бурханыг хайрлах ёстой. Чи Бурханд итгэдэг л болохоос Түүнийг хайрладаггүй, Бурханы тухай мэдлэгийг олж авааагүй, зүрх сэтгэлийн гүнээс гардаг жинхэнэ хайраар Бурханыг хэзээ ч хайрлаж байгаагүй бол Бурханд итгэх итгэл чинь ямар ч үр ашиггүй юм; хэрвээ чи Бурханд итгэхдээ Бурханыг хайрладаггүй бол чи хий дэмий амьдарч байгаа бөгөөд амьдрал чинь тэр чигээрээ бүхий л амьдралаас хамгийн дорд байдаг. Чи бүх амьдралынхаа туршид Бурханыг хэзээ ч хайрлаж, сэтгэл хангалуун байлгаж байгаагүй бол амьдрахын хэрэг юу байна? Мөн чи Бурханд итгэхийн хэрэг юу байна? Энэ чинь хүчин чармайлтын гарз бус уу? Өөрөөр хэлбэл, хэрвээ хүмүүс Бурханд итгэж, хайрлах гэж байгаа бол төлөөс төлөх ёстой. Гаднаа тодорхой нэг байдлаар үйлдэх гэж оролдохоос илүүтэйгээр зүрх сэтгэлийнхээ гүнээс жинхэнэ мэдлэг ухааныг эрж хайх хэрэгтэй. Хэрвээ чи урам зоригтойгоор дуулж, бүжиглэдэг боловч үнэнийг хэрэгжүүлж чаддаггүй бол Бурханыг хайрладаг гэж чамайг хэлж болох уу? Бурханыг хайрлахад Бурханы хүслийг бүх зүйлээс эрж хайхыг шаарддагийн дээр ямар нэгэн зүйл тохиолдох үед сэтгэлийнхээ гүнээс эрж хайн, Бурханы хүслийг ухаарч ойлгохыг оролдож, хэрэг явдлаас Бурханы хүсэл юу болох, чамайг юунд

хүрээсэй гэж Тэр хүсдэг, Түүний хүсэлд хэрхэн санаа тавих хэрэгтэйг харах гэж оролдохыг шаарддаг. Жишээ нь: Зовлон бэрхшээл туулахыг шаардсан ямар нэг зүйл тохиолдоход Бурханы хүсэл юу болох, Түүний хүсэлд хэрхэн санаа тавих хэрэгтэйгээ чи ойлгох ёстой. Чи өөрийгөө сэтгэл хангалуун байлгах ёсгүй: Эхлээд өөрийгөө хойш тавь. Махан биеэс илүү жигшүүртэй юу ч байхгүй. Чи Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрэлхийлж, үүргээ биелүүлэх ёстой. Ийм бодолтой байхад энэ хэрэг явдал дээр Бурхан чамд онцгой гэгээрэл авчирч, зүрх сэтгэл чинь бас тайтгарлыг олох болно. Чамд том ч бай, жижиг ч бай ямар нэг асуудал тохиолдоход чи эхлээд өөрийгөө хойш тавьж, махан биеийг бүх зүйлээс хамгийн дорд зүйл гэж үзэх ёстой. Чи махан биеийг хэдий чинээ их хангалуун байлгана, төдий чинээ дураараа аашилдаг; энэ удаа чи түүнийг хангалуун болговол дараагийн удаа илүү ихийг хүснэ. Ийнхүү үргэлжлэхийн хэрээр хүмүүс махан биеийг бүр ч их хайрлаж эхэлдэг. Махан бие үргэлж хэрээс хэтэрсэн хүсэлтэй, тэрийгээ хангахыг, идэх, өмсөх зүйлс байна уу, эсвэл уураа барьж дийлэхгүй байх, сул тал, залхуурлаа өөгшүүлэх байна уу аль нь ч байсан хүслийг нь хангахыг үргэлж чамаас шаарддаг… Чи махан биеийг сэтгэл хангалуун байлгах тусам дур хүсэл нь үлэмж их болж, улам цадиггүй болсоор хүмүүсийн махан бие илүү гүн гүнзгий үзэл тээж, Бурханд дуулгаваргүй хандаж, өөрийгөө өргөмжилж, Бурханы ажилд эргэлздэг болох хэмжээнд хүрдэг. Чи махан биеийг сэтгэл хангалуун байлгах тусам махан биеийн сул тал төдий чинээ их болдог; сул талыг чинь хэн ч өрөвдөхгүй байгаа мэт чамд үргэлж санагдаж, Бурхан хэтэрхий даварсан гэж чи үргэлж итгэнэ, тэгээд чи: “Бурхан яаж ийм хахир хатуу байж чадаж байна вэ? Тэр яагаад хүмүүст зөөлөн хандахгүй байна вэ?” гэж хэлэх болно. Хүмүүс махан биеийг сэтгэл хангалуун байлгаж, хэтэрхий их энхрийлэхээрээ өөрсдийгөө сүйрүүлдэг. Хэрвээ чи Бурханыг үнэхээр хайрладаг, махан биеийг сэтгэл хангалуун байлгадаггүй бол Бурханы хийдэг бүхэн маш зөв, маш сайн бөгөөд Тэрээр тэрслүү байдлыг чинь харааж, зөв шударга бус байдлыг чинь шүүх нь зүй ёсных гэдгийг харна. Бурхан чамайг цээрлүүлж, сахилгажуулан, хатуужуулах орчныг чинь бий болгож, чамайг Өөрийнхөө өмнө албадан ирүүлэх цаг ирнэ—тэр үед Бурханы хийж байгаа зүйлс гайхалтай гэдгийг чи үргэлж мэдрэх болно. Тиймээс чамд тийм ч их шаналал байхгүй мэт санагдаж, Бурхан үнэхээр хайр татам гэдгийг мэдэрнэ. Хэрвээ чи махан биеийн сул талыг өөгшүүлж, Бурхан дэндэж байна гэж хэлдэг бол үргэлж шаналж, үргэлж сэтгэлээр унаж, Бурханы бүх ажлын талаар тодорхой мэдэхгүй байхын дээр Бурхан хүний сул талуудыг огтхон ч өрөвддөггүй мэт, хүний бэрхшээлүүдийг мэддэггүй мэт санагдана. Иймээс чи туйлын шударга бус явдлыг туулсан мэт үргэлж золгүй ганцаардмал байдлыг мэдрэх үедээ гомдоллож эхэлнэ. Ийм маягаар махан биеийн сул талуудыг чи хэдий чинээ их өөгшүүлнэ, Бурхан дэндэж байна гэж улам их санагдсаар, бүр Бурханы ажлыг үгүйсгэж, Бурханыг эсэргүүцэж эхлэн, огтхон ч дуулгаваргүй байдаг болох хүртлээ дордоно. Тиймээс чи махан биеийг эсэргүүцэж, өөгшүүлэхгүй байх ёстой: “Миний нөхөр (эхнэр),

хүүхдүүд, хэтийн ирээдүй, гэрлэлт, гэр бүл—аль нь ч хамаагүй! Зүрх сэтгэлд минь Бурхан л байдаг, махан биеийг биш Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд би чадах бүхнээ хийх ёстой.” Чи ингэж шийдэх ёстой. Хэрвээ чи үргэлж ийм шийдэмгий байвал багахан хүчин чармайлтаар л үнэнийг хэрэгжүүлж, өөрийгөө хойш тавьж чадна. Урьд цагт нэгэн тариачин зам дээр хөлдөж хөшсөн могой байхыг олж үзжээ. Тариачин түүнийг аваад цээжиндээ тэвэрсэн бөгөөд амь орсныхоо дараа могой тариачныг хатгаж амийг нь хөнөөжээ гэж ярьдаг. Хүний махан бие энэ могойтой адил: Үүний мөн чанар нь хүмүүсийн амийг хорлохын төлөө байдаг учраас махан бие хүссэн бүхнээ авах үед чи амиа алддаг. Махан бие бол Сатаных. Түүнд хэрээс хэтэрсэн хүсэл байдаг, өөрийгөө л боддог, тав тухыг эдэлж, зугаа цэнгэлд умбахыг хүсэж, залхуу хойргод баригддагийн дээр тодорхой хэмжээнд сэтгэл хангалуун байлгавал эцэстээ чамайг залгих болно. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи энэ удаад үүнийг сэтгэл хангалуун байлгавал дараагийн удаа илүү ихийг хүсэж ирэх болно. Махан биед үргэлж хэрээс хэтэрсэн хүсэл, шинэ хэрэгцээ шаардлага байдаг ба чамаар бүр илүү эрхэмлүүлж, тав тухтай байдал дунд амьдрахын тулд махан биеэ өөгшүүлдгийг чинь ашигладаг—хэрвээ чи үүнийг дийлж гарч чадахгүй бол эцэстээ өөрийгөө сүйрүүлнэ. Бурханы өмнө амийг олж авч чадах эсэх, мөн эцсийн төгсгөл чинь ямар байх нь махан биеэ хэрхэн эсэргүүцэхээс чинь шалтгаалдаг. Бурхан чамайг аварч, чамайг сонгож, заяа төөргийг чинь тогтоосон атал өнөөдөр чи Түүнийг сэтгэл хангалуун байлгаж, үнэнийг хэрэгжүүлж, Бурханыг үнэхээр хайрладаг зүрх сэтгэлээр махан биеэ эсэргүүцэхийг хүсдэггүй бол эцэстээ чи өөрийгөө сүйрүүлж, улмаар асар их шаналлыг туулах болно. Хэрвээ чи махан биеийг үргэлж өөгшүүлдэг бол дотор чинь бүрмөсөн харанхуй болох тэр өдөр ирэх хүртэл Сатан аажмаар чамайг залгиж, амьгүй, эсвэл өчүүхэн ч Сүнсгүй болгож орхино. Харанхуйд амьдрах үедээ чи Сатанд олзлогдож, зүрх сэтгэлд чинь Бурхан байхаа болих бөгөөд тэр үед чи Бурханы оршихуйг үгүйсгэж, Түүнийг орхино. Тиймээс, хэрвээ хүмүүс Бурханыг хайрлахыг хүсдэг бол шаналлын төлөөс төлж, зовлон бэрхшээл туулах ёстой. Гаднаа омголон, бэрхшээл зовлонтой байж, илүү ихийг уншиж, илүү их гүйх хэрэггүй; үүний оронд тэд хэрээс хэтэрсэн бодол, хувийн ашиг сонирхол, өөрийн санаа тавьдаг зүйл, үзэл, санаа зорилго гэх мэт дотроо байдаг зүйлийг хойш тавих ёстой. Бурханы хүсэл ийм билээ.

Бурхан хүмүүсийн гадаад зан чанартай харьцах нь Түүний ажлын бас нэг хэсэг юм; жишээлбэл, хүмүүсийн гадаад, хэвийн бус хүн чанар, эсвэл тэдний амьдралын хэв маяг, зуршил, арга зам, ёс заншил, түүнчлэн тэдний гадаад хэрэгжүүлэлт болон омголон зантай харьцдаг. Гэвч Тэр үнэнийг хэрэгжүүлж, зан чанараа өөрчлөхийг хүмүүсээс шаардахдаа, тэдний дотоод санаа бодол болон үзэлтэй нь голлон харьцдаг. Зөвхөн өөрийнхөө гадаад зан чанартай харьцах тийм ч хэцүү биш; дуртай зүйлээ идэхгүй байхыг өөрөөсөө шаардахтай л адил, амархан. Гэвч доторх үзлийг чинь хөнддөг зүйлийг тавьж явуулахад тийм ч хялбар биш. Махан биеийг эсэргүүцэж, төлөөс төлж, Бурханы өмнө зовохыг энэ нь хүмүүсээс шаарддаг.

Хүмүүсийн санаа бодлын тухайд ялангуяа ийм байдаг. Бурханд итгэж эхэлсэн цагаасаа хойш хүмүүс олон буруу санаа бодол өвөрлөж ирсэн. Үнэнийг хэрэгжүүлэхгүй байх үед бүх санаа бодол чинь зөв мэт чамд санагддаг боловч ямар нэг зүйл тохиолдоход чамд маш олон буруу санаа бодол байгааг чи харах болно. Тиймээс, Бурхан хүмүүсийг төгс болгохдоо Бурханы талаарх мэдлэгт нь саад болж буй олон үзэл тэдэнд байгааг ойлгуулдаг. Санаа бодол чинь буруу гэдгийг ухаарах үедээ чи хэрвээ өөрийн үзэл болон санаа бодлын дагуу хэрэгжүүлэхээ больж чаддаг, мөн чамд юу ч тохиолдож байсан Бурханд гэрчлэл хийж, байр сууриндаа бат зогсож чаддаг бол махан биеийг эсэргүүцсэнийг чинь энэ нь нотолдог. Махан биеийг эсэргүүцэх үед чиний дотор тэмцэл болох нь гарцаагүй. Сатан хүмүүсээр өөрийгөө дагуулах гэж оролдож, махан биеийн үзлийг дагаж, махан биеийн ашиг сонирхлыг хамгаалуулах гэж оролддог—гэхдээ Бурханы үг хүмүүсийг дотроос нь гэгээрүүлж, гэрэлтүүлэх бөгөөд энэ үед Бурханыг дагах уу, эсвэл Сатаныг дагах уу гэдгээ чи өөрөө шийддэг. Бурхан гол нь хүмүүсийн дотоод зүйлтэй харьцаж, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаггүй бодол болон үзэлтэй нь харьцахын тулд үнэнийг хэрэгжүүлэхийг хүмүүсээс хүсдэг. Ариун Сүнс хүмүүсийн зүрх сэтгэлийг хөдөлгөж, гэгээрүүлж, гэрэлтүүлдэг. Иймээс болж буй бүх зүйлийн цаана тэмцэл байдаг: Хүмүүс үнэнийг, Бурханыг гэх хайрыг хэрэгжүүлэх бүрд агуу тэмцэл болж байдаг бөгөөд махан бие нь бүхэлдээ зүгээр мэт байх боловч зүрх сэтгэлийнх нь гүнд үнэндээ үхэл амьдралын тэмцэл явагдаж байх болно—энэхүү хүчтэй тэмцлийн дараа, асар их эргэцүүллийн дараа л ялалт, ялагдал нь шийдэгддэг. Хүн уйлах уу, эсвэл инээх үү гэдгээ мэддэггүй. Хүмүүсийн санаа бодлын ихэнх нь буруу, эсвэл Бурханы ажлын ихээхэн хэсэг нь тэдний үзэлтэй зөрчилддөг учраас хүмүүс үнэнийг хэрэгжүүлэх үед нүднээс далд асар их тэмцэл болж байдаг. Энэхүү үнэнийг хэрэгжүүлснээр хүмүүс, Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эргэлт буцалтгүй шийдэхээсээ өмнө бусдын нүднээс далдуур уйтгар гунигийн нулимсыг хэмжээлшгүй их урсгасан байх болно. Энэхүү тэмцлээс болж хүмүүс зовлон зүдүүр, цэвэршүүлэлт туулдаг; энэ нь жинхэнэ зовлон юм. Тэмцэл чам дээр ирэх үед хэрвээ чи Бурханы талд үнэхээр зогсож чаддаг бол Бурханыг сэтгэл хангалуун болгож чадна. Үнэнийг хэрэгжүүлэх явцад хүн дотроо зовох нь гарцаагүй; хэрвээ үнэнийг хэрэгжүүлэх үед хүмүүсийн доторх бүх зүйл зөв байдаг байсан бол тэд Бурханаар төгс болгуулах хэрэггүй, мөн ямар ч тэмцэл болохгүй, тэд зовж зүдрэхгүй байх байсан. Бурхан ашиглахад тохирохгүй олон зүйл хүмүүст байдаг, махан биеийн тэрслүү зан чанар их байдаг учраас хүмүүс махан биеийг эсэргүүцэх хичээлийг илүү гүн гүнзгий сурах хэрэгтэй байдаг. Үүнийг Бурхан зовлон гэж нэрлэдэг бөгөөд Өөртэй нь хамт үүнийг туулахыг хүнээс Тэр хүссэн. Бэрхшээлтэй тулгарах үедээ чи яаран Бурханд залбирдаг: “Өө, Бурхан минь! Би Таныг сэтгэл хангалуун байлгахыг хүсэж байна, Таны зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд сүүлчийн зовлон бэрхшээлийг туулахыг хүсэж байна, надад тулгарах саад бэрхшээл хэчнээн их байх нь хамаагүй, би Таныг сэтгэл хангалуун

байлгах ёстой. Амиа бүхэлд нь өгөх ёстой байсан ч гэсэн би Таныг сэтгэл хангалуун байлгах ёстой!” Ийм шийдэмгий байдалтайгаар, ингэж залбирахдаа чи гэрчлэлдээ бат зогсож чадна. Үнэнийг хэрэгжүүлэх болгондоо, цэвэршүүлэлт туулах бүрдээ, шалгуулах болгондоо, мөн Бурханы ажил өөрсөд дээр нь ирэх бүрд хүмүүс асар их шаналал амсах ёстой болдог. Энэ бүхэн нь хүмүүст зориулсан туршилт учраас тэдний бүгдийнх нь дотор тэмцэл болж байдаг. Энэ бол тэдний төлдөг бодит төлөөс юм. Бурханы үгийг илүү их уншиж, илүү их гүйх нь тодорхой хэмжээний төлөөс мөн. Үүнийг хүмүүс хийх учиртай, энэ бол тэдний үүрэг, тэдний биелүүлэх ёстой хариуцлага мөн боловч хүмүүс дотроо байгаа хаях хэрэгтэй зүйлсээ хаях ёстой. Тэгэхгүй бол гадаад зовлон зүдүүр чинь хэчнээн их байх, хэчнээн их гүйх чинь хамаагүй бүх зүйл хий дэмий болох болно! Өөрөөр хэлбэл, чиний дотоод өөрчлөлтүүд л гадаад зовлон зүдүүр чинь үнэ цэнтэй байх эсэхийг тодорхойлдог. Чиний дотоод зан чанар өөрчлөгдөж, үнэнийг хэрэгжүүлэх үед гадаад бүх зовлон зүдүүр чинь Бурханы сайшаалыг хүртэнэ; хэрвээ чиний дотоод зан чанарт ямар нэгэн өөрчлөлт гараагүй бол гаднаа хэчнээн их зовлон зүдүүр амсаж, хэр их гүйх чинь хамаагүй Бурханы сайшаал хүртэхгүй—Бурханы баталгаажуулаагүй зовлон бэрхшээл хий дэмий байдаг. Тиймээс чиний төлсөн төлөөсийг Бурхан сайшаах эсэх нь чамд өөрчлөлт гарсан эсэх, мөн Бурханы хүслийг хангаж, Бурханы тухай мэдлэгтэй болж, Бурханд үнэнч байхын тулд үнэнийг хэрэгжүүлж, өөрийн санаа бодол болон үзлийг эсэргүүцдэг эсэхээр чинь тодорхойлогддог. Хэчнээн их гүйх чинь хамаагүй, хэрвээ чи өөрийн санаа бодлыг эсэргүүцэхийг хэзээ ч мэдэхгүй зөвхөн гаднаа үйлдэж, омголон байхыг л эрж хайж, өөрийн аминд хэзээ ч анхаарал хандуулж байгаагүй бол зовлон бэрхшээл чинь хий дэмий байх болно. Хэрвээ тодорхой орчинд, хэлмээр байгаа зарим зүйл чамд байдаг ч үүнийг хэлэх нь буруу, ингэж хэлэх нь ах, эгч нарт ашиг тусгүй, тэднийг гомдоож болзошгүй гэж санагдвал чи үүнийг хэлэхгүйгээр дотроо шаналахыг илүүд үзнэ, учир нь эдгээр үг Бурханы хүсэлд нийцэж чадахгүй. Энэ үед чиний дотор тэмцэл өрнөх боловч чи хайртай зүйлээ орхиж, шаналахад бэлэн байна. Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд энэхүү зовлон бэрхшээлийг туулахад бэлэн байна, хэдий чи дотроо шаналах боловч махан биеийг өөгшүүлэхгүй, Бурханы зүрх сэтгэл хангалуун байх учраас чи ч бас дотроо тайвшрах болно. Энэ бол үнэхээр төлөөс төлж байгаа хэрэг бөгөөд ийм төлөөсийг Бурхан хүсдэг. Хэрвээ чи ийм маягаар хэрэгжүүлбэл Бурхан чамайг маргаангүй ерөөнө; хэрвээ чи үүнд хүрч чадахгүй бол хэр их ойлгосон, хэр сайн ярьж чаддаг чинь хамаагүй, энэ бүхэн ямар ч хэрэггүй байх болно! Хэрвээ Бурханыг хайрлах замдаа чи, Бурханыг Сатантай тулалдахад Бурханы талд зогсох чадвартай байж, Сатан руу эргэж очихгүй бол Бурханыг гэх хайрыг олж авч, гэрчлэлдээ бат зогссон байх болно.

Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй

юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг. Жишээлбэл, ах эгч нараа алагчилж үздэг бол Бурханд таалагдахгүй болов уу гэж чамд санагддаг, хэлэхийг хүсдэг үг байх боловч хэлэхгүй бол чиний дотор таагүй санагдаж, энэ мөчид чиний дотор тэмцэл эхэлнэ: “Би хэлэх үү, болих уу?” Энэ бол тэмцэл. Иймээс чамтай тулгардаг бүх зүйлд тэмцэл байдаг, чиний дотор тэмцэл байх үед, чи бодитоор хамтран ажиллаж, бодитоор зовсны ачаар Бурхан чиний дотор ажилладаг. Эцэст нь чи сэтгэл доторх асуудлыг хойш тавьж чаддаг болж, уур бухимдал аяндаа намждаг. Энэ бол Бурхантай хамтран ажилласны чинь үр дүн юм. Хүмүүс бүх зүйлийг хийхэд хүчин чармайлтдаа тодорхой хэмжээний төлөөс төлөх шаардлагатай болдог. Бодит зовлон бэрхшээлгүйгээр Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахгүй; Бурханыг сэтгэл хангалуун болгоход дөхөж очих ч үгүй, хоосон уриа лоозон урсгахаас цаашгүй! Эдгээр хоосон уриа лоозон нь Бурханыг сэтгэл хангалуун болгож чадах уу? Бурхан, Сатан хоёр сүнсний ертөнцөд тулаан хийх үед чи Бурханыг хэрхэн сэтгэл хангалуун болгож, Түүнд хийх гэрчлэлдээ хэрхэн бат зогсох ёстой вэ? Чамд тохиолддог бүхэн асар их шалгалт гэдгийг, мөн Бурхан чамаар гэрчлэл хийлгэх хэрэгтэй болох тэр цаг үеийг чи мэдэх ёстой. Гаднаа тэдгээр нь чухал биш юм шиг байж болох ч эдгээр зүйл тохиолдох үед Бурханд хайртай юу, үгүй юу гэдэг чинь харагддаг. Хэрвээ хайртай бол чи Түүнд гэрчлэл хийхдээ бат зогсож чадна, хэрвээ чи Түүнийг гэх хайрыг хэрэгжүүлээгүй бол үнэнийг хэрэгжүүлдэг хүн биш гэдгийг, мөн чамд үнэн, амь байхгүй агаад хивэг гэдгийг чинь энэ нь харуулдаг! Хүмүүст тохиолддог бүхэн нь Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсох хэрэгтэй үед нь тохиолддог. Одоохондоо чамд ямар ч томоохон зүйл тохиолдоогүй, чи агуу гэрчлэл хийдэггүй хэдий ч өдөр тутмын амьдралын чинь нарийн ширийн болгон Бурханд гэрчлэл хийх асуудал байдаг. Хэрвээ чи ах эгч нар, гэр бүлийн гишүүд, эргэн тойронд чинь байгаа хүн бүрийн бахдал бишрэлийг олж авч чадвал; хэрвээ нэгэн өдөр үл итгэгч ирээд хийдэг бүхнийг чинь биширч, Бурханы хийдэг бүхэн гайхалтай гэдгийг харвал чи гэрчлэл хийсэн байх болно. Чамд мэдлэг ухаан байхгүй, хэв чанар чинь дорд байсан хэдий ч Бурхан чамайг төгс болгосноор чи Түүнийг сэтгэл хангалуун болгож, Түүний хүсэлд санаа тавьж, Бурхан хамгийн дорд хэв чанартай хүмүүст ямар агуу ажил хийснийг бусдад харуулж чаддаг. Хүмүүс Бурханыг мэдэж авч, Сатаны өмнө ялагчид болж, Бурханд туйлын үнэнч байх үед энэ бүлэг хүмүүсээс илүү ноён нуруутай хэн ч байхгүй байх бөгөөд энэ нь хамгийн агуу гэрчлэл юм. Хэдийгээр чи агуу ажил хийх чадваргүй ч Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаг. Бусад хүн үзлээ хойш тавьж чаддаггүй боловч чи чадна; бусад хүн өөрсдийн бодит туршлагын үеэр Бурханд гэрчлэл хийж чаддаггүй ч чи бодит

биеийн хэмжээ болон үйлдлээрээ Бурханы хайрыг хариулж, Түүнд цангинасан гэрчлэл хийж чадна. Зөвхөн үүнийг л Бурханыг үнэхээр хайрлаж байгаад тооцно. Хэрвээ чи ингэж чадахгүй бол гэр бүлийнхээ гишүүд, ах эгч нарынхаа дунд, эсвэл дэлхийн хүмүүсийн өмнө гэрчлэл хийдэггүй гэсэн үг. Хэрвээ чи Сатаны өмнө гэрчлэл хийж чадахгүй бол Сатан чамайг шоолон инээж, чамайг доог тохуу, тоглоом мэт үзэх болно, тэр үргэлж чамайг шоглож, ухаан мэдрэлийг чинь алдуулна. Ирээдүйд агуу шалгалт чамд тулгарч болзошгүй боловч өнөөдөр хэрвээ чи Бурханыг үнэн сэтгэлээсээ хайрладаг бол, өмнө чинь хэчнээн агуу шалгалт байгаа нь хамаагүй, чамд юу тохиолдохоос үл хамааран, гэрчлэлдээ бат зогсож, Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаг бол зүрх сэтгэл чинь тайвширч, ирээдүйд хэчнээн агуу шалгалттай тулгарсан ч чи айхгүй. Ирээдүйд юу тохиолдохыг та нар харж чадахгүй; өнөөдрийн нөхцөл байдалд л та нар Бурханыг сэтгэл хангалуун болгож чадна. Та нар ямар нэгэн агуу ажил хийж чадахгүй бөгөөд бодит амьдрал дээр үгийг нь туулснаар Бурханыг сэтгэл хангалуун болгож, Сатаныг шившиглэх хүчтэй, цангинасан гэрчлэл хийхэд анхаарах ёстой. Хэдийгээр махан бие чинь сэтгэл хангалуун бус үлдэж, зовж шаналсан ч чи Бурханыг сэтгэл хангалуун болгож, Сатаныг ичгүүрт оруулсан байх болно. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлдэг бол Бурхан өмнөх замыг чинь нээж өгнө. Нэг л өдөр агуу шалгалт ирэхэд бусад хүн доош унах боловч чи бат зогсох чадвартай хэвээр байна: Төлсөн төлөөснөөс чинь болж Бурхан чамайг хамгаалах учраас чи бат зогсож, доош унахгүй байж чадна. Ерөнхийдөө чи үнэнийг хэрэгжүүлж, Өөрийг нь үнэхээр хайрладаг зүрх сэтгэлээр Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаг бол хожмын шалгалтуудын үеэр Бурхан чамайг гарцаагүй хамгаална. Чи мунхаг агаад биеийн хэмжээ бага, дорд хэв чанартай байсан ч Бурхан чамайг ялгаварлан гадуурхахгүй. Чиний санаа бодол зөв эсэхээс энэ нь хамаардаг. Өнөөдөр чи Бурханыг сэтгэл хангалуун болгож чадна, ингэхдээ чи хамгийн өчүүхэн жижиг зүйлд ч гэсэн анхаарал хандуулж, бүх зүйл дээр Бурханыг сэтгэл хангалуун болгож, Бурханыг үнэхээр хайрладаг зүрх сэтгэлтэй байж, чин зүрх сэтгэлээ Бурханд өгдөг бөгөөд ойлгож чадахгүй зарим зүйл байсан ч чи санаа бодлоо зөв болгож, Бурханы хүслийг эрж хайхаар Бурханы өмнө ирж, Бурханыг сэтгэл хангалуун болгохын тулд хэрэгтэй бүхнийг хийж чаддаг. Магадгүй ах эгч нар чинь чамайг хаяж болох ч зүрх сэтгэл чинь Бурханыг сэтгэл хангалуун болгож, чи махан биеийн жаргалд шунахгүй. Хэрвээ чи үргэлж ийм байдлаар хэрэгжүүлбэл агуу шалгалтууд чам дээр ирэх үед хамгаалагдах болно.

Шалгалтууд хүмүүсийн ямар дотоод байдал руу чиглэдэг вэ? Тэдгээр нь Бурханыг сэтгэл хангалуун болгох чадваргүй тэрслүү зан чанарт нь чиглэсэн байдаг. Хүмүүсийн дотор ихээхэн бохир зүйл, ихээхэн хуурамч зүйл байдаг учраас Бурхан тэднийг ариусгахын тулд шалгалтад оруулдаг. Гэхдээ хэрвээ өнөөдөр чи Бурханыг хангалуун болгож чаддаг бол ирээдүйн шалгалтууд чамайг төгс болгоно. Хэрвээ өнөөдөр чи Бурханыг сэтгэл хангалуун болгож чаддаггүй бол хожмын

шалгалтууд чамайг сорьж, чи өөрөө ч мэдэлгүй доош унана, тэр үед чи өөртөө ч тусалж чадахгүй байх болно, учир нь чи Бурханы ажилтай хөл нийлүүлж чаддаггүй, бодит биеийн хэмжээгүй байдаг. Иймээс хэрвээ чи ирээдүйд бат зогсож, Бурханыг илүү сэтгэл хангалуун байлгаж, эцсээ хүртэл Түүнийг дагаж чаддаг байхыг хүсэж байгаа бол өнөөдөр бат бөх суурь тавих ёстой. Бүх зүйл дээр үнэнийг хэрэгжүүлснээр Бурханыг сэтгэл хангалуун болгож, Түүний хүсэлд санаа тавих ёстой. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлбэл чиний дотор суурь бий болж, Өөрийг нь хайрлах зүрх сэтгэлийг Бурхан чамд төрүүлж, чамд итгэл өгөх болно. Нэг л өдөр шалгалт жинхэнээсээ тулгарахад чи зовлон шаналал ихэд амсаж, тодорхой хэмжээгээр цөхөрч, үхсэн мэт аймшигтай уй гашууг туулж магадгүй юм—гэхдээ Бурханыг гэх чиний хайр өөрчлөгдөхгүй, улам гүнзгийрэх болно. Бурханы ерөөл ийм билээ. Хэрвээ чи Бурханы өнөөдөр хэлдэг, хийдэг бүхнийг дуулгавартай зүрх сэтгэлээр хүлээн авч чаддаг бол Бурхан чамайг гарцаагүй ерөөх учраас чи Бурханаар ерөөгдсөн, Түүний амлалтуудыг хүлээн авдаг хүн болно. Хэрвээ өнөөдөр хэрэгжүүлэхгүй бол нэг л өдөр шалгалт тулгарахад чамд итгэл, хайрлах зүрх сэтгэл байхгүй байх бөгөөд тэр үед шалгалт нь уруу таталт болно; чи Сатаны уруу таталтад автаж, зугтах ямар ч аргагүй болно. Өнөөдөр, багахан шалгалт чамд тулгарахад чи бат зогсож чадах ч нэг л өдөр томоохон шалгалт тулгарахад чи гарцаагүй бат зогсож чадахгүй. Зарим хүн ихэрхүү зантай байдаг бөгөөд өөрсдийгөө аль хэдийн бараг төгс болсон гэж боддог. Хэрвээ тийм үед чи илүү гүнзгий явахгүйгээр өөртөө сэтгэл хангалуун хэвээр үлдвэл аюулд орох болно. Өнөөдөр Бурхан илүү агуу шалгалтын ажлыг хийдэггүй, бүх зүйл гаднаа зүгээр мэт харагдах боловч Бурхан чамайг шалгах үед чи хэтэрхий дутуу дулимаг гэдгээ олж мэднэ, учир нь чиний биеийн хэмжээ хэтэрхий жаахан бөгөөд чи агуу шалгалтуудыг туулах чадваргүй билээ. Хэрвээ чи байгаагаараа, үлбэгэр байдалтай хэвээр байвал шалгалт ирэхэд унана. Биеийн хэмжээ чинь хэр жижиг болохыг та нар байнга харах хэрэгтэй; ийм маягаар л та нар өсөж дэвшинэ. Хэрвээ чи зөвхөн шалгалтын үеэр л биеийн хэмжээ чинь маш жаахан, сэтгэлийн тэнхээ чинь үнэхээр сул дорой, чиний дотор бодитой зүйл хэтэрхий бага, Бурханы хүсэлд хангалтгүй гэдгээ ойлговол—тэр үед л үүнийг ойлговол хэтэрхий оройтсон байх болно.

Хэрвээ чи Бурханы зан чанарыг мэддэггүй бол шалгалтын үеэр гарцаагүй унана, яагаад гэвэл Бурхан яаж хүмүүсийг төгс болгодог, ямар арга замаар тэднийг төгс болгодгийг мэддэггүй бөгөөд Бурханы шалгалт чам дээр ирж, үзэлтэй чинь нийцэхгүй байх үед чи бат зогсож чадахгүй. Бурханы жинхэнэ хайр бол Түүний бүхий л зан чанар бөгөөд Бурханы зан чанар бүхэлдээ хүмүүст харагдах үед энэ нь махан биед юу авчирдаг вэ? Бурханы зөвт зан чанар хүмүүст харагдах үед тэдний махан бие ихээхэн өвдөлт шаналал амсах нь гарцаагүй. Хэрвээ чи энэ шаналлыг амсахгүй бол Бурханаар төгс болгуулж чадахгүй, Бурханд жинхэнэ хайрыг зориулж бас чадахгүй. Хэрвээ Бурхан чамайг төгс болговол Өөрийн бүх зан чанарыг чамд гарцаагүй харуулна. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл Бурхан

Өөрийн зан чанарыг бүхэлд нь хүнд хэзээ ч харуулж байгаагүй, харин Өөрийн урьдчилан тогтоож, сонгосон энэ бүлэг хүмүүст эцсийн өдрүүдэд илчилдэг бөгөөд хүмүүсийг төгс болгосноор Өөрийн зан чанарыг ил болгож, үүгээр дамжуулан бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгодог. Хүмүүсийн төлөө гэсэн Бурханы жинхэнэ хайр ийм билээ. Бурханы жинхэнэ хайрыг мэдрэхэд туйлын их зовлон шаналал туулж, өндөр төлөөс төлөхийг шаарддаг. Зөвхөн үүний дараа л тэд Бурханаар авхуулж, Бурханд жинхэнэ хайраа буцаан өгч чадах бөгөөд тэр үед л Бурханы зүрх сэтгэл хангалуун байх болно. Хэрвээ хүмүүс Бурханаар төгс болгуулахыг, Түүний хүслийг биелүүлж, жинхэнэ хайраа Бурханд бүрэн дүүрэн өгөхийг хүсдэг бол үхэхээс дор өвдөлтийг амсахын тулд нөхцөл байдлаасаа ихээхэн зовлон зүдүүр, тарчлалыг туулах ёстой бөгөөд эцэстээ тэд жинхэнэ зүрх сэтгэлээ Бурханд буцааж өгөхөөс аргагүй болно. Хүн Бурханд үнэхээр хайртай эсэх нь зовлон бэрхшээл болон цэвэршүүлэлтийн үеэр илчлэгддэг. Бурхан хүмүүсийн хайрыг ариусгадаг, энэ нь ч бас зовлон бэрхшээл, цэвэршүүлэлтийн дунд л хийгддэг билээ.

“МЯНГАН ЖИЛИЙН ХААНЧЛАЛ ИРЧИХСЭН” ТУХАЙ ТОВЧ ЯРИА

Мянган жилийн хаанчлалын үзэгдлийн талаар та нар юу гэж боддог вэ? Зарим хүн энэ тухай их боддог бөгөөд “Мянган жилийн хаанчлал газар дээр мянган жилийн турш оршин тогтноно, тиймээс хэрэв чуулганы ахмад гишүүд гэрлээгүй бол гэрлэх ёстой юу? Манай гэр бүл мөнгөгүй байгаа, би мөнгө олж эхлэх ёстой юу? …” гэцгээдэг. Мянган жилийн хаанчлал гэж юу вэ? Та нар мэдэх үү? Хүмүүс харалган бөгөөд асар их зовлон зүдүүр туулдаг. Үнэндээ Мянган жилийн хаанчлал хараахан албан ёсоор ирээгүй. Хүмүүсийг төгс болгох үе шатанд Мянган жилийн хаанчлал ердөө үүсэл төдий байдаг; Бурханы ярьсан Мянган жилийн хаанчлалын цаг үед хүн төгс болгуулсан байх болно. Хүмүүс ариун хүмүүс шиг байж, Синимийн газар нутагт бат зогсоно гэж өмнө нь хэлсэн. Хүмүүс төгс болгуулсан байх үед—Бурханы ярьсан ариун хүмүүс болох үед л—Мянган жилийн хаанчлал ирсэн байх болно. Бурхан хүмүүсийг төгс болгох үедээ тэднийг ариусгадаг ба тэд хэдий чинээ ариун байна, Бурханаар төдий чинээ төгс болгуулдаг. Чиний доторх бохир зүйл, тэрслүү байдал, эсэргүүцэл болон махан биеийн зүйлс хөөн зайлуулагдах үед, мөн ариусгагдсан байх үедээ чи Бурханаар хайрлуулна (өөрөөр хэлбэл, чи ариун хүн болно); Бурханаар төгс болгуулж, ариун хүн болсон үедээ чи Мянган жилийн хаанчлалд байх болно. Одоо үе бол Хаанчлалын эрин үе. Мянган жилийн хаанчлалын эрин үед хүмүүс Бурханы үгэнд найдан амьдарна, мөн бүх үндэстэн Бурханы нэрийн дор ирж, бүгд Бурханы үгийг уншихаар ирнэ. Тэр үед зарим нь утсаар залгана, зарим нь факсдана … тэд Бурханы үгэнд хандахын тулд бүхий л аргыг ашиглана, та нар ч бас Бурханы үгийн дор ирнэ. Энэ бүхэн нь хүмүүс төгс болгуулсны дараа

тохиолддог зүйл юм. Өнөөдөр хүмүүс үгээр төгс болгуулж, цэвэршүүлэгдэж, гэгээрүүлэгдэж, удирдуулдаг; энэ бол Хаанчлалын эрин үе, мөн хүмүүсийг төгс болгодог үе шат бөгөөд Мянган жилийн хаанчлалын эрин үетэй ямар ч холбоогүй. Мянган жилийн хаанчлалын эрин үед, хүмүүс аль хэдийн төгс болгуулж, тэдний доторх завхарсан зан чанар ариуссан байх болно. Тэр үед, Бурханы хэлсэн үг хүмүүсийг алхам алхмаар залж чиглүүлж, бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэлх Бурханы ажлын бүх нууцыг илчлэх бөгөөд эрин үе болгон дахь, өдөр тутам дахь Бурханы үйлдлүүдийн тухай, Тэрээр хүмүүсийг дотроос нь хэрхэн залж чиглүүлдэг тухай болон сүнсний ертөнцөд Түүний хийдэг ажлын тухай Түүний үг хүмүүст хэлж, мөн сүнсний ертөнцийн хөдөлгөөний талаар хэлнэ. Тэр үе л үнэхээр Үгийн эрин үе байх болно; одоо үе бол ердөө л үүсэл төдий юм. Хэрвээ хүмүүс төгс болгуулаагүй, ариусгагдаагүй бол газар дээр мянган жил амьдрах ямар ч аргагүй байх ба тэдний махан бие гарцаагүй илжирнэ; хэрвээ хүмүүс дотроо ариусгагдаж, Сатаных болон махан биеийнх байхаа боливол газар дээр амьд үлдэнэ. Энэ үе шатанд чи бас л харалган байна, та нарын туулдаг бүхэн бол газар дээр амьдарч буй өдөр болгондоо Бурханыг хайрлах, Түүнд гэрчлэл хийх явдал юм.

“Мянган жилийн хаанчлал ирчихсэн” гэдэг бол зөгнөл, энэ нь эш үзүүлэгчийн зөгнөлтэй төстэй бөгөөд Бурхан үүгээр ирээдүйд юу тохиолдохыг зөгнөдөг. Бурханы ирээдүйд хэлдэг үг болон өнөөдөр хэлдэг үг адилгүй: Ирээдүйн үг нь эрин үеийг залж чиглүүлнэ, харин өнөөдөр хэлдэг үг нь хүмүүсийг төгс болгож, цэвэршүүлж, тэдэнтэй харьцдаг. Ирээдүйн Үгийн эрин үе нь өнөөдрийн Үгийн эрин үеэс ялгаатай. Өнөөдөр, Бурханы хэлдэг бүх үг—ямар аргаар хэлдгээс нь үл хамааран—хүмүүсийг төгс болгох, доторх бохир зүйлийг нь ариусгах, Бурханы өмнө тэднийг ариун агаад зөв шударга болгохын төлөө байдаг. Өнөөдөр хэлдэг үг болон ирээдүйд хэлдэг үг нь хоёр тусдаа зүйл юм. Хаанчлалын эрин үед хэлдэг үг нь хүмүүсийг бүх сургалтад оруулж, хүмүүсийг бүх зүйл дээр зөв замд аваачиж, тэдний доторх бохир бүхнийг хөөн зайлуулахын төлөө байдаг. Энэ эрин үед Бурханы хийдэг зүйл энэ юм. Тэрээр хүн болгонд үгийнхээ суурийг тавьж, үгээ хүн бүрийн амь болгож, тэднийг дотроос нь байнга гэгээрүүлж, залж чиглүүлэхийн тулд үгээ ашигладаг. Бурханы хүслийг хайхрахгүй байх үед нь Бурханы үг тэднийг дотроос нь зэмлэж, сахилгажуулна. Өнөөдрийн үг хүний амь болох учиртай; тэдгээр нь хүнд хэрэгтэй бүхнийг шууд хангадаг, дотор чинь дутагдаж байгаа бүхнийг Бурханы үг хангадаг ба Бурханы үгийг хүлээн авдаг бүхэн Түүний үгийг идэж ууснаар гэгээрдэг. Ирээдүйд Бурханы хэлдэг үг бүхий л орчлон ертөнцийн хүмүүсийг залж чиглүүлдэг; өнөөдөр эдгээр үгийг Хятадад л хэлдэг бөгөөд бүхий л орчлон ертөнц даяар хэлдэг үгийг эдгээр нь төлөөлдөггүй. Мянган жилийн хаанчлал ирэх үед л Бурхан бүх орчлон ертөнцөд хандан ярина. Өнөөдөр Бурханы хэлдэг үг бүгд хүмүүсийг төгс болгохын төлөө байдаг гэдгийг мэдэж ав; энэ үе шатанд Бурханы хэлдэг үг нь хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой болохоос чамд нуущуудыг мэдэгдэх юм уу Бурханы гайхамшгуудыг харуулах зорилготой биш. Тэр олон арга барилаар ярьдаг нь хүмүүсийн хэрэгцээг

хангах зорилготой. Мянган жилийн хаанчлалын эрин үе хараахан ирээгүй—яригдаж буй Мянган жилийн хаанчлалын эрин үе нь Бурханы алдрын өдөр юм. Иудей дэх Есүсийн ажил дууссаны дараа Бурхан ажлаа Хятадын эх газарт шилжүүлж, өөр төлөвлөгөө зохиосон. Тэр та нар дээр ажлынхаа өөр нэг хэсгийг хийдэг, мөн үгээр хүмүүсийг төгс болгох ажлыг хийдэг ба хүмүүсээр асар их шаналал зовлон туулуулж, Бурханы ихээхэн нигүүлслийг тэдэнд хүртээхдээ үг ашигладаг. Ажлын энэ үе шат бүлэг ялагчдыг бий болгох ба энэхүү бүлэг ялагчдыг бий болгосны дараа тэд Түүний үйл хэргийг гэрчилж, бодит байдлыг амьдран харуулж, Түүнийг үнэхээр сэтгэл хангалуун болгож, үхэн үхтлээ Түүнд үнэнч байна, ийм маягаар Бурхан алдрыг олж авна. Бурхан алдрыг олж авах үе буюу энэ бүлэг хүмүүсийг Тэр төгс болгох үе нь Мянган жилийн хаанчлалын эрин үе байх болно.

Есүс газар дээр гучин гурван жил хагас амьдарсан. Тэр цовдлолын ажлыг хийхээр ирсэн ба цовдлолоор дамжуулан Бурхан алдрынхаа нэг хэсгийг олж авсан юм. Бурхан махбодоор ирэх үедээ даруу, нууцлаг байж, тоймгүй их зовлонг тэсвэрлэж чадсан. Тэр Бурхан Өөрөө байсан хэдий ч доромжлол, гүтгэлэг бүрийг мөн л тэвчсэн бөгөөд золин авралын ажлыг дуусгахын тулд загалмайд цовдлогдох асар их өвдөлтийг тэсвэрлэсэн билээ. Ажлын энэ үе шат дууссаны дараа Бурхан агуу алдар суу олж авсныг хүмүүс харсан хэдий ч энэ нь Түүний алдар суу бүхэлдээ биш байсан; энэ нь Есүсээс олж авсан алдрынх нь нэг хэсэг л байсан юм. Хэдийгээр Есүс бэрхшээл бүрийг тэсвэрлэж, даруу, нууцлаг байж, Бурханы төлөө цовдлогдож чадсан ч алдрынхаа нэг хэсгийг л олж авсан ба алдар суугаа Израильд олж авсан. Бурханд бас алдрын өөр нэг хэсэг бий: бодитоор ажиллаж, бүлэг хүмүүсийг төгс болгохын тулд газар дээр ирэх явдал. Есүс ажлынхаа үе шатны үеэр зарим нэг ер бусын зүйл хийсэн боловч ажлын тэр үе шат нь яавч тэмдэг, гайхамшиг л үзүүлэхийн төлөө байгаагүй. Энэ нь үндсэндээ, Есүс зовж шаналж, Бурханы төлөө цовдлогдож чадсан, мөн Бурханд хайртай учраас асар их зовлонг тэвчиж чадсан, бас Бурхан Өөрийг нь орхисон ч Бурханы хүслийн төлөө амьдралаа золиослоход бэлэн байсан гэдгийг харуулах зорилготой байсан юм. Бурхан Израиль дахь ажлаа дуусгаж, Есүс загалмайд цовдлогдсоны дараа Бурхан алдрыг олж авсан бөгөөд Сатаны өмнө гэрчлэл хийсэн билээ. Та нар Бурхан Хятадад махбод болсныг мэдээ ч үгүй, хараа ч үгүй болохоор Бурхан алдрыг олж авсаныг яаж харж чадах юм бэ? Бурхан та нар дээр байлдан дагуулалтын ихээхэн ажил хийж, та нарыг бат зогсох үед Бурханы ажлын энэ үе шат амжилттай болдог бөгөөд энэ нь Бурханы алдрын нэг хэсэг юм. Та нар үүнийг л хардаг ба Бурханаар хараахан төгс болгуулаагүй, зүрх сэтгэлээ Бурханд хараахан бүрэн өгөөгүй. Та нар энэхүү алдрыг хараахан бүхэлд нь хараагүй; Бурхан зүрх сэтгэлийг чинь аль хэдийн байлдан дагуулсан гэдгийг, Түүнийг хэзээ ч орхиж чадахгүй, эцсийг нь хүртэл Бурханыг дагана, зүрх сэтгэл чинь өөрчлөгдөхгүй гэдгийг л та нар хардаг бөгөөд энэ бол Бурханы алдар юм. Бурханы алдрыг юунаас хардаг вэ? Хүмүүс дээрх Түүний ажлын үр нөлөөнөөс. Бурхан бол маш хайр татам гэдгийг хүмүүс

хардаг, зүрх сэтгэлдээ Бурхантай байдаг, Бурханыг орхихыг хүсдэггүй бөгөөд энэ нь Бурханы алдар суу билээ. Чуулгануудын ах эгч нарын хүч нэмэгдэж, Бурханыг чин сэтгэлээсээ хайрлаж, Бурханы хийсэн ажлын хамгийн агуу сүр хүчийг болон Түүний үгийн харьцуулшгүй их сүр хүчийг харж чадах үед, Түүний үг эрх мэдэл агуулдаг, Тэрээр эзгүйрсэн хот болох Хятадын эх газарт Өөрийн ажлыг өрнүүлж чадна гэдгийг харах үед, хүмүүс хэдий сул дорой ч зүрх сэтгэл нь Бурханы өмнө бөхийж, Бурханы үгийг хүлээн авахад бэлэн байх үед, хэдийгээр тэд сул дорой, зохисгүй боловч Бурханы үг маш хайр татам, нандигнаваас зохилтой гэдгийг харж чаддаг байх үед энэ нь Бурханы алдар юм. Хүмүүс Бурханаар төгс болгуулж, Түүний өмнө бууж өгч чаддаг болж, Бурханд бүрэн дуулгавартай байж, хэтийн ирээдүй, хувь заяагаа Бурханы гарт даатгаж чадах өдөр ирэх үед Бурханы алдрын хоёр дахь хэсгийг бүрэн олж авсан байх болно. Өөрөөр хэлбэл, бодитой Бурханы ажил бүрэн дуусах үед Хятадын эх газар дахь Түүний ажил төгсөнө. Өөрөөр хэлбэл, Бурханы урьдчилан тогтоож, сонгосон хүмүүс төгс болгуулах үед Бурхан алдрыг олж авсан байх болно. Бурхан алдрынхаа хоёр дахь хэсгийг Зүүн зүгт аваачсан гэж хэлсэн, гэхдээ энэ нь энгийн нүдэнд үзэгдэхгүй. Бурхан ажлаа Зүүн зүгт аваачсан: Тэрээр аль хэдийнээ Зүүн зүгт ирчихсэн ба энэ нь Бурханы алдар юм. Өнөөдөр Түүний ажил хараахан дуусаагүй хэдий ч Бурхан ажиллахаар шийдсэн учраас энэ нь гарцаагүй гүйцэлдэнэ. Бурхан энэ ажлыг Хятадад гүйцэлдүүлэхээр шийдсэн бөгөөд та нарыг бүрэн төгс болгохоор шийдсэн. Тиймээс Тэр та нарт ямар ч гарах гарц өгдөггүй—Тэр зүрх сэтгэлийг чинь аль хэдийн байлдан дагуулсан, чи хүссэн ч, хүсээгүй ч цааш явах ёстой ба та нарыг Бурханаар авхуулах үед Бурхан алдрыг олж авдаг. Өнөөдөр, та нар хараахан төгс болгуулаагүй учраас Бурхан хараахан алдрыг олж аваагүй. Зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэж очсон хэдий ч махан биед чинь олон сул тал байсаар байгаа, та нар Бурханыг сэтгэл хангалуун болгох чадваргүй, Бурханы хүслийг анхаарч чаддаггүй, ангижрах ёстой олон сөрөг зүйлийг эзэмшсээр байдаг бөгөөд бас олон шалгалт, цэвэршүүлэлт туулах ёстой. Ийм маягаар л амь зан чанар чинь өөрчлөгдөж, Бурханаар авхуулж чадна.

БУРХАНЫГ МЭДДЭГ ХҮМҮҮС Л ТҮҮНД ГЭРЧЛЭЛ ХИЙЖ ЧАДНА

Бурханд итгэж, Бурханыг мэдэх нь тун жам ёсны, үндэслэлтэй бөгөөд өнөөдөр бие махбодтой болсон Бурхан ажлаа Өөрийн биеэр хийж байгаа эрин үе бол Бурханыг мэдэх нэн сайн цаг үе юм. Бурханыг сэтгэл хангалуун байлгах нь Бурханы хүслийг ойлгосны үндсэн дээр хийдэг зүйл бөгөөд Бурханы хүслийг ойлгохын тулд Бурханы талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Бурханы талаарх энэхүү мэдлэг нь Бурханд итгэдэг нэгэнд байх ёстой үзэгдэл юм; энэ нь хүний Бурханд итгэх

итгэлийн үндэс билээ. Энэхүү мэдлэг байхгүй бол хүний Бурханд итгэх итгэл тодорхойгүй байдалд, хоосон онол дунд орших байсан. Ийм хүмүүс Бурханыг дагахыг шийдсэн ч гэсэн юу ч олж авахгүй. Энэхүү урсгалд юу ч олж аваагүй бүх хүн таягдуулах хүмүүс юм. Тэд бүгдээрээ сорон мөлжигчид мөн. Бурханы ажлын аль ч үе шатыг туулсан бай, чамайг агуу үзэгдэл дагалдах ёстой. Эс бөгөөс, шинэ ажлын алхам бүрийг хүлээн авах нь чиний хувьд хэцүү байх байсан. Учир нь Бурханы шинэ ажил хүний төсөөлөх чадвараас хэтэрсэн, хүний сэтгэхүйн хязгаараас давсан байдаг. Иймээс хариулах хоньчингүйгээр, үзэгдлийн тухай нөхөрлөх хоньчингүйгээр хүн энэ шинэ ажлыг хүлээн авч чадахгүй. Хэрвээ хүн үзэгдлийг хүлээн авч чадахгүй бол Бурханы шинэ ажлыг хүлээн авч чадахгүй. Хэрвээ хүн Бурханы шинэ ажлыг дуулгавартай дагаж чадахгүй бол Бурханы хүслийг ойлгож чадахгүй. Иймээс Бурханы талаарх түүний мэдлэг ямар ч ач холбогдолгүй байх болно. Хүн Бурханы үгийг хэрэгжүүлэхээсээ өмнө Бурханы үгийг мэдэх ёстой, өөрөөр хэлбэл, Бурханы хүслийг ойлгох ёстой. Зөвхөн ингэж л Бурханы үгийг үнэн зөв, Бурханы хүслийн дагуу хэрэгжүүлж чадна. Энэ бол үнэнийг эрж хайдаг хүн бүрд байх ёстой зүйл, бас Бурханыг мэдэхээр хичээдэг хүн бүрийн туулах ёстой үйл явц юм. Бурханы үгийг мэдэж авах үйл явц нь Бурханыг мэдэж авах, мөн түүнчлэн Бурханы ажлыг мэдэж авах үйл явц билээ. Иймээс үзэгдлийг мэдэх гэдэг нь бие махбодтой болсон Бурханы хүн чанарыг мэдэхийг хэлэхээр үл барам, Бурханы үг болон ажлыг мэдэхийг хэлдэг. Бурханы үгээс хүмүүс Бурханы хүслийг ойлгож авч, Бурханы ажлаас Бурханы зан чанарыг, Бурхан юу болохыг мэдэж авдаг. Бурханд итгэх итгэл бол Бурханыг мэдэх эхний алхам юм. Бурханд итгэх энэхүү анхны итгэлээс Бурханд итгэх хамгийн гүн гүнзгий итгэл хүртэл ахин дэвших үйл явц нь Бурханыг мэдэж авах, Бурханы ажлыг мэдэрч туулах үйл явц билээ. Хэрвээ чи Бурханыг мэдэж авахын тулд биш, харин Бурханд итгэхийн тулд л итгэдэг бол итгэлд чинь ямар ч бодит байдал байхгүй бөгөөд итгэл чинь ариун болж чадахгүй гэдэгт эргэлзэх зүйлгүй. Хэрвээ Бурханы ажлыг туулах үйл явцдаа хүн аажмаар Бурханыг мэдэж авбал зан чанар нь аажмаар өөрчлөгдөж итгэл нь улам бүр жинхэнэ болно. Ингэж Бурханд итгэх итгэлдээ амжилт олохдоо хүн Бурханыг бүрэн олж авсан байх болно. Ажлаа Өөрийн биеэр хийхийн тулд Бурхан хоёр дахь удаагаа махбод болох гэж асар их хүчин чармайлт гаргасны шалтгаан нь хүнд Өөрийгөө мэдүүлж, Өөрийгөө харуулахад оршиж байсан. Бурханыг мэдэх[a] гэдэг нь Бурханы ажлын төгсгөлд хүрэх эцсийн үр дүн юм. Хүн төрөлхтөнд тавьдаг Бурханы сүүлчийн шаардлага энэ билээ. Өөрийн сүүлчийн гэрчлэлийн төлөө Тэр үүнийг хийдэг. Хүнийг Өөр лүүгээ эргэлт буцалтгүй, бүрэн дүүрэн эргүүлэхийн төлөө Тэр энэ ажлыг хийдэг. Хүн Бурханыг мэдэж байж л Бурханыг хайрлаж эхэлдэг бөгөөд Бурханыг хайрлахын тулд Түүнийг мэдэх ёстой. Хүн хэрхэн эрж хайх эсвэл юу олж авахаар эрж хайх нь хамаагүй Бурханы талаарх мэдлэгт хүрэх чадвартай байх

[a] Эх бичвэрт “Бурханыг мэдэх ажил” гэж байдаг.

ёстой. Зөвхөн ийм маягаар л хүн Бурханы зүрх сэтгэлийг хангалуун болгож чадна. Бурханыг мэдэж байж л хүн Бурханд жинхэнээсээ итгэж, мөн Бурханыг мэдэж байж л Түүнийг үнэхээр хүндэлж, дуулгавартай дагаж чадна. Бурханыг мэддэггүй хүмүүс Бурханыг үнэхээр дуулгавартай дагаж, хүндэлж хэзээ ч чадахгүй. Бурханыг мэдэх гэдэгт Бурханы зан чанарыг мэдэх, Түүний хүслийг ойлгох, Тэр юу болохыг мэдэх багтдаг. Гэхдээ хүн аль ч талыг нь мэдэж авсан бай, аль аль нь төлөөс төлөхийг, дуулгавартай байх хүслийг хүнээс шаарддаг. Үүнгүйгээр хэн ч эцсээ хүртэл дуулгавартай дагаж чадахгүй. Бурханы ажил хүний үзлээс хэтэрхий хол. Бурханы зан чанар, Бурхан юу болохыг мэдэхэд хүнд хэтэрхий хэцүү бөгөөд Бурханы хэлдэг, хийдэг бүхэн хүнд хэтэрхий ойлгохын аргагүй байдаг. Хэрвээ хүн Бурханыг дагахыг хүсдэг ч Түүнд дуулгавартай байх хүсэлгүй бол тэр юу ч олж авахгүй. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл, хүнд ойлгомжгүй, хүн хүлээн авахад хэцүү маш их ажлыг Бурхан хийсэн, мөн хүний үзлийг засахад хүндрэл учруулах маш ихийг Бурхан хэлсэн. Гэхдээ хүнд хэтэрхий их бэрхшээл тулгарсан болохоор Тэр ажлаа хэзээ ч зогсоогоогүй. Харин ч Тэр үргэлжлүүлэн ажиллаж, ярьж, асар олон тооны “дайчин” унаж байсан ч ажлаа хийсээр, Өөрийнх нь шинэ ажилд захирагдах хүсэлтэй бүлэг хүмүүсийг ээлж дараалан тасралтгүй сонгосоор байдаг. Унасан тэр “баатруудыг” Тэр өрөвддөггүй, харин ч Өөрийнх нь шинэ ажил, үгийг хүлээн авдаг хүмүүсийг нандигнадаг. Гэхдээ юуны төлөө Тэр ингэж алхам алхмаар ажилладаг вэ? Тэр яагаад үргэлж нэг хэсэг хүнийг таягдан хаяж, нөгөөг нь сонгож байна вэ? Тэр яагаад үргэлж ийм арга барил хэрэглэдэг вэ? Түүний ажлын зорилго бол хүнд Өөрийгөө мэдүүлж, тэгснээрээ Өөрөөр нь авхуулах боломжийг хүнд олгох явдал юм. Түүний ажлын зарчим нь өнөөдөр Түүний хийдэг ажлыг эсэргүүцдэг мөртөө өнгөрсөн үед хийсэн ажилд нь захирагддаг хүмүүс дээр ажиллах бус, харин өнөөдөр Өөрийнх нь хийдэг ажилд захирагдах чадвартай хүмүүс дээр ажиллах явдал билээ. Бурхан маш олон хүнийг таягдан хаясаар ирсний шалтгаан энэ юм.

Бурханыг мэдэж авах сургамжийг ганц хоёрхон өдрийн дотор авч чадахгүй: Хүн туршлагажиж, зовлон туулж, жинхэнээсээ захирагддаг болох ёстой. Юуны өмнө Бурханы ажил болон үгээс эхэл. Бурханы тухай мэдлэгт юу багтдаг, энэ мэдлэгт хэрхэн хүрэх болон туршлагаараа Бурханыг яаж харахыг чи ойлгох шаардлагатай. Бурханыг хараахан мэдэхгүй байхдаа хүн бүрийн хийх ёстой зүйл нь энэ юм. Бурханы ажил, үгийг хэн ч нэг дор ухаарч чадахгүй бөгөөд хэн ч Бурханы талаарх бүрэн дүүрэн мэдлэгт богинохон хугацаанд хүрч чадахгүй. Үүнд шаардлагатай туршлагажих арга барил байдаг агаад үүнгүйгээр хэн ч Бурханыг мэдэж, Бурханыг чин сэтгэлээсээ дагаж чадахгүй. Бурхан хэдий чинээ их ажил хийнэ, хүн Түүнийг төдий чинээ их мэдэж авдаг. Бурханы ажил хүний үзэлтэй зөрчилдөх тусам, Түүний талаарх хүний мэдлэг төдий чинээ шинэчлэгдэж, гүнзгийрч байдаг. Хэрвээ Бурханы ажил үүрд нэгэн хэвийн, өөрчлөгдөхгүй хэвээр байдаг байсан бол Түүний талаарх хүний мэдлэг их биш байх байсан. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл

Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үед Бурхан юу хийсэн, Хаанчлалын эрин үед Тэр юу хийдэг гээд эдгээр үзэгдлийн талаар та нар тов тодорхой мэдэх ёстой. Та нар Бурханы ажлыг мэдэх ёстой. Петр Есүсийг дагаж байж л Есүст хийсэн Сүнсний ажлаас нэлээдийг нь аажмаар мэдэж авсан. Тэрээр “Хүний туршлагад түшиглэх нь бүрэн мэдлэгт хүрэхэд хангалттай биш; Бурханыг мэдэхэд бидэнд туслах олон шинэ зүйл Түүний ажилд байх ёстой” гэж хэлсэн. Есүс бол элч нарын адилаар Бурханы илгээсэн нэгэн гэж Петр эхэндээ итгэж, Есүсийг Христ гэж үздэггүй байсан. Өөрийг нь дагаж эхлэх үед Есүс Петрээс “Ионагийн хүү Симон оо, чи Намайг дагах уу?” гэж асуусан. Петр, “Тэнгэрлэг Эцэгийн илгээсэн нэгнийг би дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг би хүлээн зөвшөөрөх ёстой. Би Таныг дагах болно” гэж хариулсан юм. Петрийн үгээс Есүсийн талаар тэр ямар ч мэдлэггүй байсныг харж болно; тэр Бурханы үгийг туулж, өөртэйгөө харьцаж, Бурханы төлөө зовлон туулсан боловч Бурханы ажлын талаар ямар ч мэдлэггүй байсан. Хэсэг хугацаанд туршлагажсаны дараа Петр Бурханы олон үйл хэргийг Есүсээс олж харж, Бурханы хайр татам байдлыг харж, Бурханы оршихуйгаас нэлээдийг нь Есүсээс олж харсан. Есүсийн хэлсэн үгийг хүн хэлж чадахгүй, Есүсийн хийсэн ажлыг хүн хийж чадахгүй байсан гэдгийг ч бас тэр харсан юм. Түүнчлэн Петр Бурханы мэргэн ухаанаас ихээхнийг, бурханлаг чанарын ихээхэн ажлыг Есүсийн үг болоод үйлдлээс харсан. Туршлагажих явцдаа тэр зөвхөн өөрийгөө мэдээд зогсохгүй, Есүсийн үйлдэл бүрийг сайтар анхаарч, үүнээсээ олон шинэ зүйл олж мэдсэн; тухайлбал, Есүсээр дамжуулан Бурханы хийсэн ажилд бодитой Бурханы олон илэрхийлэл байсан бөгөөд хэлсэн үг, хийсэн үйлдэл, түүнчлэн чуулганууды хариулсан байдал, хэрэгжүүлсэн ажлаараа Есүс энгийн хүнээс ялгаатай байлаа. Иймээс Петр сурах ёстой олон хичээлээ Есүсээс авсан бөгөөд Есүсийг загалмайд цовдлогдох гэж байх үед Есүсийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон байв. Тэрхүү мэдлэг нь насан туршдаа Есүст үнэнч байж, Эзэний төлөө толгойгоо доош харуулж цовдлогдохынх нь үндэс болсон юм. Хэдийгээр тэр эхэндээ зарим нэг үзэлтэй, Есүсийн талаар тодорхой мэдлэггүй байсан боловч эдгээр нь завхарсан хүнд зайлшгүй байдаг зүйл юм. Явах гэж байхдаа Өөрийнх нь хийх гэж ирсэн ажил нь цовдлуулалт байсан гэдгийг Есүс Петрт хэлсэн: Эрин үе Түүнийг хаяж, энэхүү бузар заваан хуучин эрин үе Түүнийг загалмайд цовдлох нь зайлшгүй шаардлагатай зүйл байв; Тэр золин авралын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд ирсэн агаад энэ ажлыг гүйцэлдүүлснээр Түүний үйлчлэл дуусах байлаа. Үүнийг сонсоод Петр уй гашууд автаж, Есүст бүр ч их татагдсан юм. Есүсийг загалмайд цовдлогдох үед Петр ганцаархнаа гашуудан уйлжээ. Үүний өмнөхөн тэр Есүсээс “Эзэн минь! Өөрийгөө цовдлогдоно гэж Та хэлэх юм. Явсны тань дараа хэзээ бид Тантай дахин уулзах вэ?” гэж асуусан. Түүний хэлсэн үгэнд ямар ч хольц байгаагүй юу? Ямар ч үзэл холилдоогүй байсан уу? Бурханы ажлын нэг хэсгийг гүйцэлдүүлэхээр Есүс ирсэн, Есүсийг явсны дараа Сүнс өөртэй нь хамт байх болно, хэдий Есүс загалмайд цовдлогдож, тэнгэрт өргөгдсөн ч гэсэн Бурханы Сүнс өөртэй нь хамт

байна гэдгийг Петр зүрх сэтгэлдээ мэдэж байв. Тухайн үед Петр Есүсийн талаар зарим нэг мэдлэгтэй болсон байсан: Есүсийг Бурханы Сүнс илгээсэн, Бурханы Сүнс Түүний дотор байдаг, Есүс бол Бурхан Өөрөө, Тэр бол Христ гэдгийг тэр мэдэж байсан юм. Гэсэн ч Есүсийг гэх хайр, мөн хүний сул дорой байдлынхаа улмаас Петр тийм үг хэлжээ. Хэрвээ хүн Бурханы ажлын алхам бүрд ажиглаж, хичээнгүйлэн туршлагажиж чадвал Бурханы хайр татам байдлыг аажмаар олж мэдэж чадах болно. Паулын үзэгдэл юу байсан бэ? Есүс өөрт нь харагдах үед Паул “Та хэн бэ, Эзэн минь?” гэсэн. Есүс “Би бол чиний хяхан хавчдаг Есүс байна” гэж хэлсэн юм. Энэ нь Паулын үзэгдэл байв. Петр Есүсийн амилал болон 40 өдрийн турш харагдсаныг нь, мөн Есүсийн амьдарч байх хугацааны номлолыг өөрийн аяны төгсгөл хүртэл үзэгдлээ болгосон юм.

Хүн Бурханы ажлыг туулж, өөрийгөө мэдэж авч, завхарсан зан чанараасаа ангижирч, амийн өсөлтийг эрж хайх нь бүгд Бурханыг мэдэхийн төлөө байдаг. Хэрвээ чи зөвхөн өөрийгөө мэдэж, завхарсан зан чанартайгаа харьцахыг л хичээдэг атлаа Бурхан хүн дээр ямар ажил хийдэг, Түүний аврал хэр агуу болох, хэрхэн Бурханы ажлыг туулж, Бурханы үйл хэргийг нүдээр харах тухай ямар ч мэдлэггүй бол туршлага чинь ямар ч утгагүй. Үнэнийг хэрэгжүүлж, тэвчиж чаддаг л бол амь нь төлөвшсөн байгаа гэж чи бодож байвал амийн жинхэнэ утга учрыг эсвэл хүнийг төгс болгох Бурханы зорилгыг бас л ухаараагүй байна гэсэн үг юм. Нэг л өдөр чи шашны чуулгануудад, Гэмшлийн Чуулган юм уу Амийн Чуулганы гишүүдийн дунд ороод, залбирал нь “үзэгдлийг” агуулдаг, амийг эрж хайхдаа үгээр замчлуулж, сэтгэл нь хөдөлдөг үнэн сүсэгт олон хүнтэй таарах болно. Түүнчлэн, олон хэрэг явдал дээр тэд тэвчиж, өөрсдийгөө хойш тавьж, махан биедээ захирагдахгүй байж чаддаг. Тэр үед чи ялгааг нь хэлж чадахгүй: Тэдний хийдэг бүхнийг зөв, амийн төрөлхийн илэрхийлэл гэж чи бодно, харин тэдний итгэдэг нэр буруу байдаг нь хэчнээн харамсалтай билээ. Тийм үзэл бодол мунхаг биш гэж үү? Олон хүнд амь байдаггүй гэж яагаад хэлдэг вэ? Учир нь тэд Бурханыг мэддэггүй болохоор зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй, тэдэнд амь байхгүй гэж хэлдэг. Хэрвээ Бурханд итгэх итгэл чинь тодорхой түвшинд хүрч, Бурханы үйл хэрэг, Бурханы бодит байдал, Бурханы ажлын үе шат бүрийг бүрэн дүүрэн мэдэх чадвартай болсон бол чи үнэнийг эзэмшсэн байна. Хэрвээ чи Бурханы ажил болон зан чанарыг мэддэггүй бол туршлагад чинь ямар нэг зүйл дутуу л байна. Есүс ажлынхаа тэр үе шатыг хэрхэн хэрэгжүүлсэн, энэ үе шат хэрхэн хэрэгжиж байгаа, Нигүүлслийн эрин үед Бурхан ажлаа хэрхэн хийсэн, ямар ажил хийгдсэн, энэ үе шатанд ямар ажил хийгдэж байгаа гээд эдгээр зүйлийн талаар чи нэгд нэгэнгүй мэдэхгүй бол хэзээ ч итгэлтэй байж чадахгүй, үргэлж тээнэгэлзэх болно. Хэсэг хугацаанд туршлагажсаны дараа чи Бурханы хийсэн ажлыг, Түүний ажлын алхам бүрийг мэдэж чадвал, мөн Бурхан үгээ хэлж байгаагийн зорилго, Түүний хэлсэн ийм их үг яагаад биелээгүй тухай бүрэн дүүрэн мэдлэг олж авсан бол сэтгэлийн түгшүүр, цэвэршүүлэлтээс ангид байж, түдгэлзэлгүйгээр, зоригтойгоор өмнөх

замаа даган явж чадна. Бурхан Өөрийн ажлаас үлэмж ихийг нь ямар аргаар биелүүлдгийг та нар харах ёстой. Тэр Өөрийн хэлдэг үгийг ашиглан, олон янзын үгээр дамжуулан хүнийг цэвэршүүлж, хүний үзлийг өөрчилдөг. Та нарын амссан бүх зовлон, туулсан бүх цэвэршүүлэлт, дотроо хүлээн авсан харьцалт, туулсан гэгээрэл бүхэн Бурханы хэлсэн үгээр дамжин биелсэн юм. Юунаас болж хүн Бурханыг дагадаг вэ? Бурханы үгээс болж! Бурханы үг туйлын нууцлагаас гадна хүний зүрх сэтгэлийг хөдөлгөж, сэтгэлийнх нь гүн дэх зүйлсийг илчилж, өнгөрсөнд болсон зүйлсийг хүнд мэдүүлж, ирээдүйд болох зүйлсийг тодорхой харах боломж олгож чаддаг. Иймээс Бурханы үгээс болж хүн зовлон туулж, мөн Бурханы үгээс болж төгс болгуулдаг: Энэ үед л хүн Бурханыг дагадаг. Энэ үе шатанд хүний хийх ёстой зүйл бол Бурханы үгийг хүлээн авах явдал бөгөөд төгс болгуулах ч бай, цэвэршүүлэлт амсах ч бай, гол түлхүүр нь Бурханы үг билээ. Энэ бол Бурханы ажил, бас өнөөдөр хүний мэдвэл зохих үзэгдэл юм.

Бурхан хүнийг яаж төгс болгодог вэ? Бурханы зан чанар юу вэ? Түүний зан чанарт юу агуулагддаг вэ? Энэ бүх зүйлийг тодруулбал: үүнийг Бурханы нэрийг түгээх гэж нэрлэдэг, үүнийг Бурханд гэрчлэл хийх, Бурханыг өргөмжлөх гэж нэрлэдэг. Бурханыг мэдсэн суурин дээр үндэслэн эцэстээ хүний амь зан чанар өөрчлөгдөнө. Хүн хэдий чинээ их харьцалт, цэвэршүүлэлт туулна, төдий чинээ хүч чадалтай байдаг; Бурханы ажлын үе шат олон байх тусам, хүн төдий чинээ төгс болгуулдаг. Өнөөдөр хүний туршлагаар бол, Бурханы ажлын алхам бүр нь хүний үзэл рүү дайрч, хүний оюун ухааныг бүгд даван гарч, хүлээлтээс нь давсан байдаг. Бурхан хүнийг хэрэгтэй бүхнээр нь хангадаг атал энэ нь бүх талаараа хүний үзэлтэй зөрчилддөг. Чамайг сул дорой байх үед Бурхан Өөрийн үгийг айлддаг; ингэж л Тэр чиний амийг хангаж чаддаг. Чиний үзэл рүү дайрснаараа Тэр чамаар Бурханы харьцалтыг хүлээн авхуулдаг; зөвхөн ингэж л чи завхралаасаа ангижирч чадна. Өнөөдөр, бие махбодтой болсон Бурхан нэг талаараа бурханлаг чанар дотор ажилладаг боловч нөгөө талаараа хэвийн хүн чанараар ажилладаг. Бурханы хийдэг ямар ч ажлыг чи үгүйсгэхгүй байж, Бурхан хэвийн хүн чанараар юу ч хэлж, хийсэн бай захирагдаж чаддаг болж, Тэр хэчнээн хэвийн харагдсан ч хамаагүй Түүнд захирагдаж, Түүнийг ойлгож чаддаг болж, бодит туршлагатай болох үедээ л Тэр бол Бурхан гэдгийг чи гарцаагүй мэдэж, чамд ямар ч үзэл төрөхөө больж, Түүнийг эцсээ хүртэл дагах чадвартай болно. Бурханы ажилд мэргэн ухаан байдаг. Түүний гэрчлэлд хүн хэрхэн бат зогсож чадахыг Тэр мэддэг. Хүний амин газар хаана оршдогийг Тэр мэддэг, Түүний хэлдэг үг чиний амин газарт цохиж чаддаг боловч Тэр бас сүр жавхлант, мэргэн үгээрээ чамайг Өөрийн гэрчлэлд бат зогсоодог. Бурханы гайхамшигт үйл хэрэг ийм билээ. Бурханы хийдэг ажил хүний оюун ухаанд төсөөлөхийн аргагүй. Махан биетэй оршихуй болох хүнд ямар төрлийн завхрал байдаг, хүний гол чанарыг юу бүрдүүлдэг гээд энэ бүхнийг Бурханы шүүлт илчилдэг нь хүнийг ичгүүрээ нуух газаргүй болгодог.

Өөрийнх нь тухай мэдлэгийг хүн олж аваасай гэсэндээ, мөн Өөрийнхөө гэрчлэлийн төлөө Бурхан шүүлт, гэсгээлтийн ажил хийдэг. Завхарсан зан чанарыг

нь Тэр шүүхгүй л бол хүн, халдахыг тэвчдэггүй Түүний зөвт зан чанарыг мэдэж чадахгүй, Бурханы талаарх хуучин мэдлэгээ шинэ болгож бас чадахгүй байх байсан. Өөрийн гэрчлэлийн төлөө, Өөрийн удирдлагын төлөө Тэр Өөрийгөө бүхэлд нь ил болгож, улмаар ил тод илрэлтээрээ дамжуулан Бурханы талаарх мэдлэгт хүрч, зан чанараа өөрчилж, Бурханд цангинасан гэрчлэл хийх боломжийг хүнд олгодог. Бурханы төрөл бүрийн олон ажлаар дамжуулан хүний зан чанарт өөрчлөлт гардаг; зан чанар нь ингэж өөрчлөгдөхгүйгээр хүн Бурханд гэрчлэл хийж, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадахгүй. Хүний зан чанарын өөрчлөлт нь хүн өөрийгөө Сатаны хүлээс, харанхуйн нөлөөнөөс чөлөөлж, үнэхээр Бурханы ажлын үлгэр дуурайл, загвар, Бурханы гэрч, Бурханы зүрх сэтгэлийн дагуу байдаг нэгэн болсныг илтгэдэг. Өнөөдөр, бие махбодтой болсон Бурхан газар дээр ажлаа хийхээр ирсэн бөгөөд Өөрийнх нь талаар мэдлэгтэй болж, Өөрт нь дуулгавартай байж, Өөрийг нь гэрчилж, Өөрийнх нь бодитой агаад хэвийн ажлыг мэдэж, хүний үзэлтэй нийцдэггүй Өөрийнх нь бүх үг, ажлыг дуулгавартай дагаж, хүнийг аврахаар Өөрийнх нь хийдэг бүх ажил хийгээд хүнийг байлдан дагуулахаар гүйцэлдүүлдэг Өөрийнх нь бүх үйл хэрэгт гэрчлэл хийхийг хүнээс шаарддаг. Бурханд гэрчлэл хийдэг хүмүүс Бурханы тухай мэдлэгтэй байх ёстой; ийм гэрчлэл л үнэн зөв, бодитой байдаг, ийм гэрчлэл л Сатаныг ичээж чадна. Шүүлт, гэсгээлт болон харьцалт, засалтыг нь туулж Түүнийг мэдэж авсан хүмүүсийг Бурхан Өөртөө гэрчлэл хийлгэхэд ашигладаг. Өөртөө гэрчлэл хийлгэхдээ Тэр Сатаны завхруулсан хүмүүсийг ашиглаж, зан чанар нь өөрчлөгдөж, Түүний ерөөлийг хүртсэн хүмүүсийг ч бас ашигладаг. Хүн зөвхөн амаараа магтах нь Түүнд хэрэггүй, мөн Өөрийнх нь авраагүй Сатаны төрлийнхний магтаал, гэрчлэл ч Түүнд хэрэггүй. Бурханыг мэддэг хүмүүс л Бурханд гэрчлэл хийхэд тохирно, зан чанар нь өөрчлөгдсөн хүмүүс л Түүнд гэрчлэл хийхэд тохирно. Өөрийнх нь нэрийг санаатайгаар шившиглэхийг Бурхан хүнд зөвшөөрөхгүй.

ПЕТР ЕСҮСИЙГ ХЭРХЭН МЭДЭЖ АВСАН ТУХАЙ

Есүстэй хамт өнгөрөөсөн хугацаандаа Петр, Есүсээс олон хайр татам чанарыг, даган дуурайхуйц олон талыг болон өөрийг нь хангасан олон талыг олж харжээ. Хэдийгээр Петр олон арга замаар Бурханы оршихуй болон хайр татам байдлыг Есүсээс олж харсан боловч анх тэрээр Есүсийг мэдээгүй юм. Петр Есүсийг 20 настай байхаасаа дагаж эхэлсэн бөгөөд зургаан жилийн турш үргэлжлүүлэн дагажээ. Энэ хугацаанд тэр Есүсийг хэзээ ч мэдэж аваагүй; Петр дан ганц бахдал бишрэлээрээ Есүсийг дагахад бэлэн байлаа. Есүс анх түүнийг Галил нуурын эрэг дээр байхад нь дуудаад: “Ионагийн хүү Симон оо, чи Намайг дагах уу?” гэж асуужээ. Петр: “Би тэнгэрлэг Эцэгийн илгээсэн хүнийг дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Би Таныг дагана” гэсэн юм. Тухайн үед

Петр, хамгийн агуу эш үзүүлэгч, Бурханы хайртай Хүү болох Есүс нэртэй хүний тухай яриаг сонссон байсан бөгөөд Түүнийг олно гэдэгтээ байнга найдаж, мөн Түүнийг харах боломж тохионо гэдэгт найдаж байв (учир нь Ариун Сүнс түүнийг ийнхүү удирдаж байлаа). Хэдий Петр Түүнийг хэзээ ч харж байгаагүй, харин Түүний тухай цуу яриа л сонсож байсан боловч Петрийн зүрх сэтгэлд Есүсийг гэх хүсэл тэмүүлэл, бишрэл хүндэтгэл аажмаар өсөж, нэг л өдөр Есүсийг харна хэмээн байнга эрмэлзэж байв. Есүс Петрийг хэрхэн дуудсан бэ? Тэр ч бас Петр гэдэг хүний тухай яриаг сонссон, гэхдээ Ариун Сүнс Түүнд: “Галил хэмээх нуур луу яв, тэнд Ионагийн хүү Симон хэмээх нэгэн байгаа” хэмээн зааварчлаагүй юм. Есүс, Ионагийн хүү Симон хэмээх хүн байдаг, хүмүүс түүний номлолыг сонсдог бөгөөд тэр ч бас тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, түүнийг сонссон хүмүүсийн сэтгэл хөдлөн уйлж байсан гэж хэн нэгний ярихыг сонсжээ. Үүнийг сонссоныхоо дараа Есүс тэр хүнийг дагаж, Галил нуур луу очсон; Петр Есүсийн дуудлагыг хүлээн авч, Түүнийг дагасан билээ.

Есүсийг дагах хугацаанд Петрт Есүсийн талаар олон санаа бодол төрсөн бөгөөд Түүнийг үргэлж өөрийн өнцгөөс шүүдэг байв. Петр Сүнсний талаар тодорхой түвшний ойлголттой байсан хэдий ч түүний ойлголт зарим талаар тодорхой бус байсан тул тэрээр: “Би тэнгэрлэг Эцэгийн илгээсэн хүнийг дагах ёстой. Ариун Сүнсний сонгосон нэгнийг би хүлээн зөвшөөрөх ёстой” гэж хэлсэн юм. Тэрээр Есүсийн хийсэн зүйлсийг ойлгоогүй, тэдгээрийг тодорхой мэдээгүй. Есүсийг хэсэг хугацаанд дагасныхаа дараа тэр Есүсийн хэлсэн, хийсэн зүйлийг болон Есүсийг Өөрийг нь сонирхож эхэлсэн. Есүс хайр, хүндэтгэлийн аль алиныг төрүүлж буйг тэр мэдэрсэн; тэр Түүнтэй холбогдож, Түүний дэргэд байх дуртай байсан бөгөөд Есүсийн үгийг сонсох нь түүнд хангалт, тусламж үзүүлсэн юм. Есүсийг дагасан хугацаандаа Петр, Түүний амьдралын бүх зүйлийг буюу үйлдэл, үг, хөдөлгөөн, илэрхийллийг нь ажиглаж, үнэн сэтгэлээсээ авч үзсэн. Тэгээд Есүс бол эгэл хүмүүстэй адилгүй гэх гүн гүнзгий ойлголтыг олж авчээ. Хэдийгээр Есүсийн гадаад төрх дэндүү хэвийн байсан ч Тэрээр хүнийг гэх хайр, энэрэл, хүлээцтэй байдлаар дүүрэн байсан юм. Түүний хийсэн, эсвэл хэлсэн бүхэн нь бусдад асар их тус дэм болсон бөгөөд Петр өмнө нь хэзээ ч хараагүй, өөрт нь ч бас байгаагүй зүйлсийг Есүсээс харж, олж авсан. Хэдийгээр Есүст асар том бие бялдар ч, ер бусын хүн чанар ч байхгүй боловч Түүнд үнэхээр хосгүй, эгэл бус байдал байдаг гэж Петр харсан юм. Петр үүнийг бүрэн тайлбарлаж чадахгүй байсан хэдий ч Есүс өрөөл бусдаас өөрөөр үйлддэгийг харсан, учир нь Түүний хийсэн зүйлс хэвийн хүмүүсийн хийдгээс тун өөр байсан билээ. Есүстэй харилцсан цагаасаа хойш Петр, Түүний зан араншин жирийн хүнийхээс өөр гэдгийг бас харжээ. Есүс үргэлж тууштай үйлддэг, хэзээ ч яардаггүй, аливааг хэзээ ч дэгсдүүлдэггүй, эсвэл дарж хэлдэггүй, харин хэвийн агаад биширмээр зан араншинг харуулан амьдардаг байлаа. Ярихдаа Есүс илэн далангүй, нигүүлсэнгүй ярьж, үргэлж хөгжилтэй атлаа амарлингуй байдлаар ярилцдаг байсан ч Өөрийнхөө ажлыг гүйцэтгэхдээ эрхэм

чанараа хэзээ ч алдаагүй юм. Есүс заримдаа үг дуу цөөтэй байх мөртөө бусад үед зогсоо чөлөөгүй ярьж байхыг Петр харсан. Заримдаа Тэр маш их баярласандаа наадан тоглож, дэвэн дэгдэх тагтаа мэт харагддаг байсан ч зарим үед маш их гунигласандаа юу ч ярилгүй, орь гунигт автан, хал үзэж, хашир суусан эх хүн шиг байдаг байв. Заримдаа Тэр дайснаа устгахаар давшиж буй баатарлаг цэрэг шиг уур хилэнгээр дүүрэн байдаг ба заримдаа бүр архирч буй арслантай төстэй байдаг байлаа. Заримдаа Тэр баярлан инээж, бусад үед нь залбирч, уйлж байв. Есүс хэрхэн авирлаж байснаас үл хамааран, Петр Түүнийг хязгааргүй хайрлаж, хүндлэх болжээ. Есүсийн инээд түүнийг аз жаргалаар бялхуулж, Есүсийн уй гашуу түүнийг уйтгар гунигт автуулж, уур хилэн нь түүнийг айлгаж, харин өршөөл, уучлал, хүмүүст тавьдаг хатуу чанд шаардлага нь түүнийг Есүст үнэхээр хайртай болгож, Түүнийг үнэхээр хүндэлж, хүсэн тэмүүлэх эрмэлзлийг нь бий болгожээ. Мэдээж, Петр хэдэн жилийн турш Есүсийн хажууд амьдарч байхдаа энэ бүхнийг аажмаар ухаарч эхэлсэн юм.

Петр төрөлхийн саруул ухаантай, гойд хэрсүү хүн байсан боловч Есүсийг дагах үедээ олон тэнэг зүйл хийжээ. Бүр анх, Есүсийн талаар зарим нэг үзэл түүнд байлаа. Тэрээр: “Хүмүүс Таныг эш үзүүлэгч гэдэг, тэгвэл Та найман настай, юмны учир ойлгож эхэлж байхдаа Бурхан гэдгээ мэдэж байсан уу? Та Ариун Сүнснээс олдсон гэдгээ мэдэж байсан уу?” гэж асуусан юм. Есүс хариуд нь: “Үгүй ээ, Би мэдээгүй! Би чамд ердөө л маш эгэл жирийн хүн шиг санагдаж байгаа биз дээ? Би бусадтай адилхан. Эцэгийн илгээдэг хүн бол ер бусын биш, харин хэвийн л хүн. Хэдийгээр Миний хийдэг ажил тэнгэрлэг Эцэгийг минь төлөөлдөг боловч Миний дүр, хүн болох Би, энэхүү махан бие тэнгэрлэг Эцэгийг минь бүрэн төлөөлж чадахгүй, харин Түүний нэг хэсгийг л төлөөлж чадна. Хэдий Би Сүнснээс ирсэн боловч хэвийн хүн хэвээр бөгөөд Миний Эцэг Намайг ер бусын нэгэн биш, жирийн хүн болгон энэ газар дэлхий рүү илгээсэн юм” гэжээ. Петр үүнийг сонсох үедээ л Есүсийн талаар бага зэргийн ойлголттой болсон юм. Тэрээр Есүсийн ажил, сургаал, хариулга, хангалтын тоо томшгүй олон цагийг туулсныхаа дараа л тун гүн гүнзгий ойлголт олж авчээ. 30 настай байхдаа Есүс Петрт удахгүй болох цовдлолынхоо талаар хэлж, бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд ажлын нэг үе шатыг—цовдлолын ажлыг хийхээр ирсэн гэдгээ хэлсэн. Есүс бас, цовдлолоос гурав хоногийн дараа хүний Хүү дахин амилна, амилангуутаа хүмүүст 40 хоног харагдана гэдгийг Петрт хэлсэн юм. Энэ үгийг сонсоод Петр гуниглаж, эдгээр үгийг үнэн сэтгэлээсээ авч үзсэн; тэр үеэс эхлээд тэрээр Есүстэй улам илүү дотно байх болжээ. Хэсэг хугацаанд туршлагажсаны дараа Петр, Есүсийн хийсэн бүхэн нь Бурханы оршихуйнх гэдгийг ухаарч эхэлсэн бөгөөд Есүс бол гойд хайр татам гэж бодох болжээ. Ийм ойлголттой болох үед л Ариун Сүнс түүнийг дотроос нь гэгээрүүлсэн юм. Тэр үед Есүс шавь нар болон бусад дагалдагчдадаа хандан: “Иохан, чи Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээн асуужээ. Иохан: “Та бол Мосе” гэв. Дараа нь Тэр Лукт хандан: “Лук, чи Намайг хэн гэж хэлэх вэ?” гэхэд Лук: “Та бол

хамгийн агуу эш үзүүлэгч” гэжээ. Дараа нь нэгэн эгчээс асуухад тэрээр: “Та бол мөнхөөс мөнхөд олон үг хэлдэг хамгийн агуу эш үзүүлэгч билээ. Хэний ч зөгнөл Таных шиг агуу байдаггүй, мөн хэний ч мэдлэг Таныхаас давдаггүй; Та бол эш үзүүлэгч” гэв. Дараа нь Есүс Петрт хандан: “Петр, чи Намайг хэн гэж хэлэх вэ?” гэж асуулаа. Петр хариуд нь: “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн. Та тэнгэрээс ирсэн, Та газрынх биш, Та Бурханы бүтээлүүдтэй адилгүй. Бид газар дээр байдаг, Та бидэнтэй хамт энд байгаа боловч Та бол тэнгэрийнх, Та энэ дэлхийнх биш, мөн Та газрынх биш” гэсэн юм. Туршлагаар нь дамжуулан Ариун Сүнс түүнийг гэгээрүүлж, ийм ойлголтод хүрэх боломж олгожээ. Энэ гэгээрлийн дараа тэрээр Есүсийн хийсэн бүхнийг бүр ч их гайхан биширч, Түүнийг бүр илүү хайр татам гэж бодсон бөгөөд зүрх сэтгэлдээ Есүсээс хагацах ер дургүй байв. Иймээс Есүс цовдлогдоод дахин амилсныхаа дараа анх удаа Петрт Өөрийгөө харуулахад Петр ер бусын аз жаргалтайгаар: “Эзэн минь! Та дахин амилжээ!” хэмээн дуу алдсан юм. Тэгээд уйлангаа Петр тун том загас барьж хоол хийн, Есүст өргөн барьжээ. Есүс инээмсэглэсэн боловч үг хэлсэнгүй. Петр Есүсийн дахин амилсныг мэдэж байсан хэдий ч үүний нууцыг ойлгоогүй байв. Түүнийг Есүст загас идүүлэхээр өгөх үед Есүс татгалзаагүй боловч үг хэлээгүй, мөн хооллохоор суугаагүй. Харин гэнэт алга болжээ. Энэ нь Петрийг асар их цочролд оруулсан бөгөөд тэр үед л дахин амилсан Есүс нь урьдын Есүсээс өөр болохыг ойлгосон юм. Үүнийг ухаармагцаа Петр гашуудсан боловч Эзэн ажлаа биелүүлснийг мэдээд бас тайтгарчээ. Есүс Өөрийн ажлыг гүйцэтгэсэн, хүнтэй хамт байх хугацаа нь дууссан, мөн тэр цагаас эхлээд хүн өөрийнхөө замаар алхах ёстой болсон гэдгийг Петр мэдлээ. Есүс нэгэнтээ түүнд: “Чи ч бас Миний уусан гашуун аяганаас уух ёстой (үүнийг Тэр амиллынхаа дараа хэлсэн). Чи ч бас Миний алхсан замаар алхах ёстой. Миний төлөө амиа өгөх ёстой” гэж хэлсэн юм. Одоогоос ялгаатай нь тухайн үеийн ажил нүүр тулсан яриа хэлбэртэй байгаагүй. Нигүүлслийн эрин үед Ариун Сүнсний ажил нэн нууцлаг байсан ба Петр ихээхэн бэрхшээл туулсан юм. Заримдаа Петр: “Бурхан минь! Надад энэ амиас өөр юу ч байхгүй. Хэдийгээр энэ нь Таны хувьд төдийлөн үнэ цэнгүй боловч би үүнийгээ Танд зориулахыг хүсэж байна. Хэдий хүмүүс Таныг хайрлахад тохирохгүй, хайр болон зүрх сэтгэл нь үнэ цэнгүй боловч Та хүмүүсийн чин сэтгэлийн хүслийг мэддэг гэж би итгэж байна. Хүмүүсийн бие Таны зөвшөөрөлд нийцэхгүй ч гэсэн би Танаас зүрх сэтгэлийг минь хүлээн авахыг хүсэж байна” хэмээн уулга алдахад хүрдэг байлаа. Ийм залбирлыг хэлж, ялангуяа: “Би зүрх сэтгэлээ Бурханд бүрэн зориулахыг хүсэж байна. Хэдийгээр би Бурханы төлөө юу ч хийж чадахгүй боловч үнэнчээр Бурханыг сэтгэл хангалуун байлгаж, өөрийгөө Түүнд чин сэтгэлээсээ зориулахыг хүсэж байна. Бурхан зүрх сэтгэлийг минь гарцаагүй харна гэдэгт би итгэж байна” хэмээн залбирах үедээ тэр урам зориг авдаг байв. Тэрээр: “Бурханыг хайрлах бодол болон чин сэтгэлийн хүслийг минь Бурхан хүлээн зөвшөөрөөсэй гэдгээс өөр юуг ч би амьдралдаа гуйхгүй. Би Эзэн Есүстэй маш удаан хугацаанд хамт байсан ч Түүнийг хэзээ ч хайрлаж байгаагүй;

энэ бол миний хамгийн том өр. Би Түүнтэй хамт байсан ч гэсэн Түүнийг мэдээгүй, тэр ч байтугай Түүний ар хударгаар зохисгүй зүйл хэлж байсан. Эдгээр зүйлийг бодохоор би Эзэн Есүст улам их өртэй санагддаг" гэж хэлсэн юм. Тэр үргэлж ийм байдлаар залбирдаг байв. Тэрээр: "Би тоос шорооноос ч өчүүхэн. Энэ үнэнч сэтгэлээ Бурханд зориулахаас өөр хийж чадах зүйл надад үгүй" хэмээн хэлжээ.

Петрийн туршлага оргилдоо хүрч, түүний бие бараг бүхэлдээ тамирдсан ч Есүс дотроос нь зоригжуулсаар байлаа. Тэгээд Есүс нэг удаа Петрт үзэгджээ. Петр асар их зовж, зүрх сэтгэл нь шархалсан мэт санагдаж байх үед Есүс түүнд ийнхүү зааварчилсан юм: "Чи газар дээр Надтай хамт байсан, Би чамтай хамт энд байсан. Хэдийгээр өмнө нь бид тэнгэрт хамт байсан ч энэ нь эцсийн эцэст сүнсний ертөнцийнх юм. Одоо Би сүнсний ертөнцөд эргэн очсон, чи газар дээр байна. Учир нь Би газрынх биш, хэдий чи ч бас газрынх биш боловч чи газар дээр өөрийн чиг үүргийг биелүүлэх ёстой. Чи зарц тул үүргээ биелүүлэх ёстой." Бурханы хажууд буцаж очиж чадна гэдгээ сонсоод Петр тайтгарчээ. Петр тийнхүү тэсэхийн аргагүй шаналж, бараг хэвтэрт орох үедээ: "Би маш их завхарсан болохоор Бурханыг сэтгэл хангалуун байлгах чадваргүй" гэж хэлэх хүртлээ харуусан гэмшсэн юм. Есүс түүнд үзэгдэж: "Петр ээ, чи нэгэнтээ Миний өмнө гаргаж байсан шийдвэрээ мартчихсан юм гэж үү? Чи үнэхээр Миний хэлсэн бүхнийг мартчихсан юм уу? Чи Надад өгсөн шийдвэрээ мартчихсан юм уу?" гэжээ. Есүсийн байгааг хараад Петр орноосоо өндийхөд Есүс түүнийг ингэж тайтгаруулсан юм: "Би газрынх биш гэдгээ чамд аль эрт хэлсэн—үүнийг чи ойлгох ёстой, гэхдээ чамд Би бас нэг зүйл хэлснийг чи мартчихав уу? 'Чи ч бас газрынх биш, энэ дэлхийнх биш.' Яг одоо хийх хэрэгтэй ажил чамд байна. Чи энэ мэт гашуудаж болохгүй. Чи ингэж зовж болохгүй. Хэдийгээр хүн, Бурхан хоёр нэг ертөнцөд хамт оршиж чадахгүй ч Надад Миний ажил, чамд чиний ажил байгаа, чиний ажил дуусах тэр өдөр бид нэг ертөнцөд хамтдаа байж, Би чамайг Өөртэйгөө үүрд хамт байлгана." Энэ үгийг сонссоныхоо дараа Петр тайтгарч, санаа нь амарсан. Энэ зовлон нь түүний тэвчих ёстой, туулах ёстой зүйл гэдгийг тэрээр мэдсэн бөгөөд тэр цагаас хойш зориг оржээ. Есүс ялангуяа гол чухал мөчүүдэд түүнд харагдаж, онцгой гэгээрэл, удирдамж өгч, түүн дээр ихээхэн ажил хийж байсан юм. Петр юунд хамгийн их харамсаж байсан бэ? Петрийг "Та бол амьд Бурханы Хүү" гэж хэлсний дараахан Есүс Петрээс өөр нэг асуулт асуусан (гэхдээ үүнийг Библид ийм маягаар тэмдэглээгүй байдаг). Есүс: "Петр ээ! Чи Намайг ер нь хайрлаж байсан уу?" гэж түүнээс асуусан юм. Түүний хэлж байгааг Петр ойлгоод: "Эзэн минь! Би нэгэнтээ тэнгэр дэх Эцэгийг хайрлаж байсан боловч Таныг хэзээ ч хайрлаж байгаагүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна" гэжээ. Тэгэхэд Есүс: "Хэрвээ хүмүүс тэнгэр дэх Эцэгийг хайрладаггүй бол газар дээрх Хүүг хайрлаж яахан чадах билээ? Хэрвээ хүмүүс Эцэг Бурханы илгээсэн Хүүг хайрладаггүй бол яаж тэнгэр дэх Эцэгийг хайрлаж чадах билээ? Хэрвээ хүмүүс газар дээрх Хүүг үнэхээр хайрладаг бол тэнгэр дэх Эцэгийг ч үнэхээр хайрладаг" гэв. Петр энэ үгийг сонсоод, дутагдлаа ухаарчээ. Тэрээр "Би тэнгэр дэх Эцэгийг

нэгэнтээ хайрласан боловч Таныг хэзээ ч хайрлаагүй” хэмээх үгээсээ болж нулимс урсгах хэмжээнд үргэлж харуусдаг байлаа. Есүсийг дахин амилж, дээш өргөгдсөний дараа тэрээр энэ үгэндээ бүр ч их харуусаж, гашууджээ. Урьдын ажил болон одоогийн биеийн хэмжээгээ эргээд бодохоороо тэр үргэлж Есүсийн өмнө очин залбирч, Бурханы хүслийг хангалуун байлгаагүй, мөн Бурханы стандартад нийцэхгүй байгаадаа үргэлж харамсан, өртэй санагддаг байлаа. Эдгээр асуудал нь түүний хамгийн том ачаа болсон билээ. Тэрээр: “Нэг л өдөр би Танд өөрт байгаа бүхнийг болон өөрийгөө бүхэлд нь зориулна, би Танд хамгийн үнэ цэнтэй болгоныг өгнө” гэсэн. Тэрээр: “Бурхан минь! Надад нэг л итгэл, нэг л хайр бий. Амь минь ямар ч үнэ цэнгүй, бас бие минь ч үнэ цэнгүй. Надад нэг л итгэл, нэг л хайр бий. Оюун ухаанд минь Танд итгэх итгэл, зүрх сэтгэлд минь Таныг хайрлах хайр байдаг; Танд миний өгч чадах зүйл өөр юу ч биш, энэ хоёр л байна” гэжээ. Петр Есүсийн үгээр асар их зоригжсон, учир нь цовдлогдохоосоо өмнө Есүс түүнд: “Би энэ дэлхийнх биш, чи ч бас энэ дэлхийнх биш” гэсэн. Дараа нь Петрийг асар их өвдөх үед Есүс түүнд: “Петр ээ, чи мартчихав уу? Би дэлхийнх биш, Өөрийнхөө ажлын төлөө л Би арай эрт явж одсон. Чи ч бас дэлхийнх биш, чи үнэхээр мартчихаа юу? Би чамд хоёр удаа хэлсэн, санахгүй байна уу?” хэмээн сануулсан юм. Үүнийг сонсоод Петр: “Би мартаагүй!” гэв. Тэгэхэд Есүс ингэж хэлсэн: “Чи нэгэнтээ тэнгэрт Надтай хамт аз жаргалтай байж, хэсэг хугацааг Миний хажууд өнгөрүүлсэн. Чи Намайг санаж, Би чамайг санадаг. Хэдийгээр Миний нүдээр бол бүтээлүүдийг дурдахын ч хэрэггүй боловч гэм зэмгүй агаад хайр татам нэгнийг Би яаж хайрлахгүй байж чадах юм бэ? Чи Миний амлалтыг мартчихаа юу? Чи газар дээрх Миний даалгаврыг хүлээн зөвшөөрөх ёстой; Миний даалгасан үүргийг биелүүлэх ёстой. Нэг л өдөр Би чамайг заавал хажуудаа аваачна.” Үүнийг сонсоод Петр улам их зоригжиж, бүр ч их урам зориг авсан болохоор загалмай дээр байхдаа тэр: “Бурхан минь! Би Таныг хангалттай хайрлаж чадахгүй! Та надаас үхэхийг гуйсан ч гэсэн би Таныг бас л хангалттай хайрлаж чадахгүй! Та сүнсийг минь хааш нь ч илгээсэн, Өөрийнхөө урьдын амлалтыг биелүүлэх ч бай, үгүй ч бай, дараа нь Та юу ч хийсэн бай, би Таныг хайрлаж, Танд итгэдэг” гэж хэлж чадсан юм. Тэрээр өөрийн итгэл, жинхэнэ хайрыг баримталж байлаа.

Нэгэн орой Петрийг оролцуулаад хэдэн шавь нар загас агнуурын завин дээр Есүстэй хамт байсан ба Петр Есүсээс маш гэнэн асуулт асууж: “Эзэн минь! Их удаан бодсон нэг асуултаа би Танаас асуумаар байна” гэсэн. Есүс: “Тэгвэл асуу, асуу!” гэж хариулав. Петр тэгэхэд нь: “Хуулийн эрин үед хийгдсэн ажил Таны хийсэн зүйл байсан уу?” гэжээ. Есүс: “Энэ хүүхэд, хэчнээн ч гэнэн юм бэ дээ!” гэж буй мэт инээмсэглэв. Дараа нь Тэр зоримгоор цааш үргэлжлүүлэн: “Энэ Минийх байгаагүй. Энэ бол Ехова болон Мосегийн хийсэн зүйл байсан юм” гэжээ. Петр үүнийг сонсоод дуу алдан: “Өө! Тэгвэл Таны хийсэн зүйл биш байжээ” гэв. Петрийг ингэж хэлмэгц Есүс өөр юу ч хэлсэнгүй. Петр дотроо: “Үүнийг Та хийгээгүй юм байна, тэгэхээр энэ Таны хийсэн зүйл биш болохоор хуулийг үгүй хийхээр ирсэнд

тань гайхах юм алга” гэж бодлоо. Түүний зүрх сэтгэл ч бас уужирчээ. Дараа нь Есүс, Петр нэлээд гэнэн гэдгийг ухаарсан боловч тухайн үед Петрт ямар ч ойлголт байгаагүй учраас Есүс өөр юу ч хэлээгүй, түүнийг шууд няцаагаагүй. Нэг удаа Есүсийг синагогт номлол айлдахад Петрийг оролцуулаад олон хүн тэнд байжээ. Номлолдоо Есүс: “Мөнхөөс мөнхөд ирэх Нэгэн бүх хүн төрөлхтнийг нүглээс золин аврахын тулд Нигүүлслийн эрин үед золин авралын ажлыг хийх боловч хүнийг нүглээс хөтлөн гаргахдаа ямар ч дүрмээр хязгаарлагдахгүй. Тэрээр хуулиас алхан гарч, Нигүүлслийн эрин үед орно. Бүх хүн төрөлхтнийг золин аварна. Тэр Хуулийн эрин үеэс Нигүүлслийн эрин үе рүү алхах боловч Еховагаас ирсэн Түүнийг хэн ч мэдэхгүй. Мосегийн хийсэн ажлыг Ехова хайрласан; Еховагийн хийсэн ажлаас үүдэн Мосе хуулийг боловсруулсан” гэв. Ингэж хэлмэгцээ Тэр: “Нигүүлслийн эрин үед Нигүүлслийн эрин үеийн тушаалуудыг хүчингүй болгодог хүмүүст гай гамшиг тохионо. Тэд сүмд зогсоод Бурханы сүйрлийг хүлээн авах ёстой ба тэдэн дээр гал бууна” хэмээн үргэлжлүүллээ. Эдгээр үгийг сонссон нь Петрт бага зэргийн нөлөө үзүүлсэн бөгөөд туршлагажих хугацаанд нь Есүс Петрийг хариулж, хангаж, чин сэтгэлээсээ ярилцаж байсан тул энэ нь Петрт Есүсийн талаар арай илүү ойлголт өгсөн юм. Петр тухайн өдөр Есүсийн номлосон зүйл, загас агнуурын завин дээр байх үедээ Есүсээс асуусан асуулт, Есүсийн өгсөн хариулт, мөн түүнчлэн Тэр хэрхэн инээмсэглэсэн тухай бодох үедээ л энэ бүхнийг эцэст нь ойлгож авсан билээ. Дараа нь Ариун Сүнс Петрийг гэгээрүүлсэн бөгөөд тэр үед л Петр Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг ойлгосон. Петрийн ойлголт Ариун Сүнсний гэгээрлээс урган гарсан боловч ойлголт нь тодорхой үйл явцтай байлаа. Асуулт асууж, Есүсийн номлохыг сонссоноор, тэгээд Есүсийн онцгой нөхөрлөл, онцгой хариулгыг хүлээн авснаар Петр, Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг ухаарчээ. Ийм ухааралд нэг л шөнийн дотор хүрсэн юм биш; үүнд үйл явц байсан бөгөөд түүний хожмын туршлагад тус нэмэр болсон юм. Есүс төгс болгох ажлыг бусад хүмүүст хийгээгүй мөртөө яагаад зөвхөн Петрт л хийсэн юм бэ? Учир нь, Есүс бол амьд Бурханы Хүү гэдгийг зөвхөн Петр л ойлгосон; өөр хэн ч үүнийг мэдээгүй. Түүнийг дагаж байх хугацаандаа ихийг мэдсэн олон шавь байсан боловч тэдний мэдлэг өнгөцхөн байв. Ийм учраас Есүс Петрийг төгс болгуулах үлгэр загвар болгон сонгосон юм. Есүс тэр үед Петрт хэлсэн зүйлээ өнөөдөр хүмүүст хэлдэг бөгөөд тэдний мэдлэг болон амийн оролт Петрийн дайд хүрэх ёстой. Энэ шаардлага болон энэ замын дагуу Бурхан хүн бүрийг төгс болгоно. Өнөөдөр яагаад хүмүүсээс бодит итгэл, жинхэнэ хайртай байхыг шаарддаг вэ? Петрийн туулсан зүйлийг та нар ч бас туулах ёстой; Петрийн туршлагаараа олж авсан үр жимс та нараас ч бас харагдах ёстой; Петрийн амссан зовлон шаналлыг та нар ч бас гарцаагүй туулах ёстой. Та нарын алхдаг зам Петрийн алхаж байсантай адилхан. Та нарын амсдаг шаналал бол Петрийн амссан зовлон шаналал юм. Та нар алдрыг хүлээн авах үедээ, мөн бодит амьдралыг амьдран харуулах үедээ Петрийн дүрийг амьдран харуулдаг. Зам нь

адилхан бөгөөд үүнийг дагаснаар хүн төгс болгуулдаг. Гэсэн хэдий ч, Петрийнхтэй харьцуулахад та нарын хэв чанар арай дутуу дулимаг байдаг, учир нь цаг үе өөрчлөгдсөн, хүмүүсийн завхралын хэмжээ ч бас өөр болсон, түүнчлэн Иудей нь эртний соёлтой, урт удаан оршин тогтносон хаант улс байлаа. Тиймээс та нар хэв чанараа сайжруулахын тулд чадах бүхнээ хийх ёстой.

Петр маш хэрсүү, хийдэг юм бүхэндээ самбаатай, туйлын үнэнч шударга хүн байсан юм. Тэр олон бүтэлгүйтэл амссан. Тэрээр 14 настайдаа нийгэмд хөл тавьж, сургуульд сурч байсны зэрэгцээ синагогт ойр ойрхон очдог байв. Тэр ихээхэн урам зоригтой, цуглаанд оролцоход үргэлж бэлэн байдаг байлаа. Тэр үед Есүс Өөрийнхөө ажлыг хараахан албан ёсоор эхлээгүй байв; энэ нь ердөө Нигүүлслийн эрин үеийн эхлэл байсан юм. Петр 14 настайдаа шашны хүмүүстэй харилцаж эхэлсэн; 18 настайдаа тэрээр шашны дээдчүүлтэй холбоо тогтоосон ч нүднээс далд өрнөдөг шашны эмх замбараагүй байдлыг харсныхаа дараа орхин явжээ. Энэ хүмүүс хэчнээн зальхай, башир, хуйвалдаач болохыг хараад тэр туйлын их зэвүүцсэн (түүнийг төгс болгохын тулд тухайн үед Ариун Сүнс ийнхүү ажилласан юм. Тэр ялангуяа түүний сэтгэлийг хөдөлгөж, түүнд зарим нэгэн онцгой ажил хийсэн), иймээс тэр 18 настайдаа синагогоос гарсан юм. Эцэг эх нь түүнийг хяхан хавчиж, итгүүлэхгүй байв (тэд диаволд харьяалагддаг, үл итгэгчид байсан). Эцэст нь Петр гэрээ орхиод хаа сайгүй аялж, хоёр жилийн турш загасчилж, номлол айлдсан бөгөөд энэ хугацаанд тэр бас нэлээд хэдэн хүнийг удирдаж байлаа. Одоо чи Петрийн явсан яг тэр замыг тодорхой харж чадах ёстой. Хэрвээ чи Петрийн замыг тодорхой харж чаддаг бол өнөөдөр хийгдэж байгаа ажлын талаар тодорхой мэдэж байх тул гомдоллож, идэвхгүй болохгүй, эсвэл ямар нэгэн зүйлийг хүсэн эрмэлзэхгүй. Чи тухайн үеийн Петрийн сэтгэл санааны байдлыг мэдрэх ёстой: Тэр уй гашууд автсан; ямар нэг ирээдүйг, эсвэл ямар нэгэн ерөөлийг гуйхаа больсон. Тэр ашиг хонжоо, аз жаргал, алдар нэр, эсвэл дэлхий дээрх эд хөрөнгийг эрж хайгаагүй; зөвхөн хамгийн утга учиртай амьдралаар амьдрах гэж эрэлхийлсэн ба энэ нь Бурханы хайрыг хариулж, өөртөө байгаа хамгийн эрхэм нандин зүйлийг Бурханд зориулахын төлөө байлаа. Тэгвэл тэр сэтгэл хангалуун байх байв. Тэрээр: “Эзэн Есүс Христ ээ, би нэгэнтээ Таныг хайрласан боловч Таныг хэзээ ч үнэхээр хайрлаагүй. Хэдийгээр би Танд итгэдэг гэж хэлсэн боловч хэзээ ч Таныг үнэн сэтгэлээсээ хайрлаагүй. Би Таныг хүндэлж, Таныг гайхан биширч, Таныг санаснаас л биш, хэзээ ч Таныг хайрлаагүй, бас Танд жинхэнээсээ итгээгүй” хэмээх үгээр Есүст ихэвчлэн залбирдаг байв. Петр шийдвэрээ гаргахын тулд байнга залбирч, Есүсийн үгээр үргэлж зоригжиж, үүнээс сэдэл авдаг байжээ. Хожим нь, хэсэг хугацаанд туршлагажсаных нь дараа Есүс түүнийг шалгаж, Өөрийг нь улам илүү хүсэн эрмэлзэхэд хүргэсэн юм. Тэрээр: “Эзэн Есүс Христ минь! Би Таныг хэчнээн их санаж, Таныг харахыг хэчнээн хүсэж байна гээч. Би маш дутуу дулимаг бөгөөд Таны хайрыг нөхөж чадахгүй. Намайг хурдан авахыг би Танаас гуйж байна. Танд би хэзээ хэрэгтэй болох юм бэ? Та намайг хэзээ авах юм бэ? Би хэзээ Таны царайг

дахин нэг удаа харах вэ? Би цаашид энэ биед амьдарч, үргэлжлүүлэн завхарсаар байхыг хүсэхгүй байна, дахиад тэрслэхийг ч хүсэхгүй байна. Би өөрт байгаа бүхнээ Танд аль болох хурдан зориулахад бэлэн байна, цаашид Таныг гуниглуулахыг хүсэхгүй байна" гэсэн юм. Тэр ийнхүү залбирсан боловч Есүс түүний юуг төгс болгохыг тухайн үед мэдээгүй байлаа. Туршилтад зовж шаналах үеэр Есүс түүнд дахин харагдаж: "Петр ээ, Би чамайг төгс болгохыг хүсэж байна, тэгснээр чи үр жимс буюу Би чамайг төгс болгосны биелэл болж, үүнийг Би таалах болно. Чи үнэхээр Намайг гэрчилж чадах уу? Миний хий гэж шаардсаныг чи хийсэн үү? Чи Миний хэлсэн үгийг амьдран харуулсан уу? Чи нэгэнтээ Намайг хайрласан боловч Намайг амьдран харуулсан уу? Чи Миний төлөө юу хийсэн бэ? Чи Миний хайрыг хүртэх үнэ цэнгүй гэдгээ хүлээн зөвшөөрдөг мөртөө Миний төлөө юу хийсэн юм бэ?" гэжээ. Петр Есүсийн төлөө юу ч хийгээгүйгээ ойлгосон бөгөөд Бурханы төлөө амиа өгөх урьдын тангаргаа санав. Иймээс тэр дахиж гомдоллоогүй бөгөөд дараа нь түүний залбирал хавьгүй илүү дээр болжээ. Тэр залбирч, "Эзэн Есүс Христ минь! Би нэгэнтээ Таныг орхиж, Та ч бас нэгэнтээ намайг орхисон. Бидэнд тусдаа байсан цаг хугацаа бий, мөн хамтдаа байсан цаг хугацаа бий. Гэсэн ч Та намайг өрөөл бусдаас илүү хайрладаг. Би Таны эсрэг ахин дахин тэрсэлж, Таныг удаа дараа гуниглуулсан. Би яаж ийм зүйлийг мартаж чадах билээ? Таны надад хийсэн ажил, надад даалгасан зүйлийг би хэзээ ч марталгүй, үргэлж сэтгэлдээ тээж байгаа. Таны надад хийсэн ажлын төлөө би чадах бүхнээ хийсэн. Юу хийж чадахыг минь Та мэддэг, ямар үүрэг гүйцэтгэж чадахыг минь ч Та мэддэг. Би Таны зохион байгуулалтад захирагдахад бэлэн байна, би өөрт байгаа бүхнээ Танд зориулна. Таны төлөө юу хийж чадахыг минь зөвхөн Та л мэднэ. Хэдийгээр би Сатанд маш их хууртаж, Таны эсрэг тэрсэлсэн боловч тэдгээр гэм нүглээр минь Та намайг санадаггүй, тэдгээрт үндэслэн надад ханддаггүй гэдэгт би итгэдэг. Би бүхий л амьдралаа Танд зориулахыг хүсэж байна. Би юу ч гуйхгүй, мөн надад өөр ямар ч итгэл найдвар, төлөвлөгөө байхгүй; би зөвхөн Таны санаа зорилгын дагуу үйлдэж, Таны хүслийг биелүүлэхийг л хүсэж байна. Би Таны гашуун аяганаас ууж, Танд захирагдана" хэмээн хэлсэн юм.

Та нар алхаж байгаа замынхаа талаар тодорхой мэдэж байх ёстой; ирээдүйд явах замынхаа талаар, Бурхан юуг төгс болгох талаар болон та нарт юу даалгасан талаар тодорхой мэдэж байх ёстой. Магадгүй нэг л өдөр та нарыг шалгана, тэр цаг ирэхэд та нар Петрийн туршлагаас урам зориг авч чадвал үнэхээр Петрийн замаар алхаж байгааг чинь энэ нь харуулна. Бурхан Петрийг жинхэнэ итгэл, хайрынх нь төлөө, бас Өөрт нь үнэнч байсных нь төлөө сайшаасан юм. Үнэнч шударга зантай, зүрх сэтгэлдээ Бурханыг хүсэн эрмэлзэж байсных нь төлөө Бурхан түүнийг төгс болгосон билээ. Хэрвээ чамд үнэхээр Петрийнх шиг хайр, итгэл бий бол Есүс чамайг гарцаагүй төгс болгоно.

ХҮН ЦЭВЭРШҮҮЛЭЛТИЙГ ТУУЛЖ БАЙЖ Л ЖИНХЭНЭ ХАЙРЫГ ОЛЖ АВЧ ЧАДНА

Та нар бүгд шалгалт, цэвэршүүлэлт дунд байдаг. Цэвэршүүлэлтийн үеэр Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Цэвэршүүлэлт туулснаар хүмүүс Бурханд жинхэнэ магтаал өргөж чаддаг бөгөөд цэвэршүүлэлтийн дундаас өөрсдийгөө тун их дутуу дулимаг гэдгээ ойлгож чаддаг. Цэвэршүүлэлт хэдий чинээ их байна, махан биеэ төдий чинээ хаяж чаддаг; цэвэршүүлэлт нь хэдий чинээ их байна, Бурханыг хайрлах хүмүүсийн хайр төдий чинээ их байдаг. Энэ бол та нарын ойлгох ёстой зүйл юм. Яагаад хүмүүс цэвэршүүлэгдэх ёстой вэ? Ямар үр дүнд хүрэхээр зорьдог вэ? Хүнийг цэвэршүүлэх Бурханы ажлын ач холбогдол юу вэ? Чи үнэхээр Бурханыг эрж хайдаг бол тодорхой хэмжээнд Түүний цэвэршүүлэлтийг туулсныхаа дараа маш сайн, туйлын шаардлагатай гэдгийг нь мэдэрнэ. Цэвэршүүлэлтийн үеэр хүн Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Бурханы цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрөхийн тулд гэж Түүнийг хайрлахаар шийдсэнээр: Цэвэршүүлэлтийн үеэр дотроо тарчилж, зүрхийг чинь хутгаар сийчиж байгаа мэт байдаг ч Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээр чи Түүнийг сэтгэл хангалуун болгохыг хүсдэг бөгөөд махан биеэ анхаарахыг хүсдэггүй. Бурханыг гэх хайрыг хэрэгжүүлнэ гэж үүнийг хэлдэг. Дотроо шархалж, зовлон чинь тодорхой хэмжээнд хүрсэн ч чи Бурханы өмнө очиж, “Өө Бурхан минь! Би Таныг орхиж чадахгүй. Дотор минь харанхуй байгаа ч би Таныг сэтгэл хангалуун болгохыг хүсэж байна; Та миний зүрх сэтгэлийг мэднэ, Таныг надад хайраа илүү их зориулаасай гэж би хүсэх байна” хэмээн залбирахад бэлэн хэвээр байдаг. Энэ бол цэвэршүүлэлтийн үеийн хэрэгжүүлэлт юм. Бурханыг гэх хайрыг сууриа болговол цэвэршүүлэлт чамайг Бурханд илүү ойртуулж, Бурхантай илүү ойр дотно болгож чадна. Бурханд итгэдэг учраас чи зүрх сэтгэлээ Бурханд өргөн барих ёстой. Хэрвээ чи зүрх сэтгэлээ Бурханд өргөж, Түүний өмнө дэлгэвэл цэвэршүүлэлтийн үеэр Бурханыг үгүйсгэх, Түүнийг орхин явах боломжгүй байх болно. Ингэснээр Бурхантай харилцах харилцаа чинь улам ойр дотно, улам хэвийн болж, Бурхантай улам ойр ойрхон ярих болно. Үргэлж ийм маягаар хэрэгжүүлбэл чи Бурханы гэрэлд, үгийнх нь удирдамж дор илүү их цагийг өнгөрөөж, зан чанарт чинь бас улам их өөрчлөлт гарч, мэдлэг чинь өдөр өдрөөр нэмэгдэнэ. Бурханы шалгалт гэнэт чам дээр буух өдөр ирэх үед чи Бурханы дэргэд байж чадах төдийгүй Түүнд гэрчлэл хийж чадна. Тэр үед чи Иов болон Петр шиг байна. Бурханд гэрчлэл хийснээрээ Түүнийг үнэхээр хайрлаж, Түүний төлөө баяртайгаар амиа өгнө; чи Бурханы гэрч, Бурханы хайртай нэгэн байх болно. Цэвэршүүлэлт туулсан хайр сул дорой биш, харин хүчтэй байдаг. Бурхан чамайг хэзээ, хэрхэн шалгалт туулуулахаас үл хамааран чи амьдрах, үхэх эсэхээ ч хайхралгүй, Бурханы төлөө бүхнийг дуртайяа хөсөр хаяж, Бурханы төлөө юуг ч баяртайяа тэвчиж чадваас хайр чинь цэвэр ариун, итгэл чинь бодитой байх болно. Тэгсэн цагт л чи үнэхээр Бурханаар хайрлагдсан нэгэн, үнэхээр Бурханаар төгс болгуулсан нэгэн байх болно.

Хэрвээ хүмүүс Сатаны нөлөөнд орвол Бурханыг хайрлах тэдний хайр үгүй болж, урьдын үзэгдэл, хайр, шийдвэр нь алга болсон байдаг. Хүмүүс Бурханы төлөө зовох учиртай гэж боддог байсан боловч өнөөдөр ингэхийг ичгүүртэй гэж үзэн, ихээхэн гомдол гаргадаг. Энэ бол Сатаны ажил, хүн Сатаны эзэмшил дор орсны шинж юм. Ийм байдалтай тулгарвал чи залбирч, аль болох хурдан үүнийг засах ёстой—энэ нь чамайг Сатаны дайралтаас хамгаална. Гашуун цэвэршүүлэлтийн үеэр хүн Сатаны нөлөөнд хамгийн амархан ордог. Тэгвэл ийм цэвэршүүлэлтийн үеэр чи Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Чи хүсэл зоригоо дайчилж, Бурханы өмнө зүрх сэтгэлээ дэлгэж, үлдсэн цаг хугацаагаа Түүнд зориулах ёстой. Бурхан чамайг яаж ч цэвэршүүллээ гэсэн, чи Бурханы хүслийг хангахын тулд үнэнийг хэрэгжүүлж чаддаг байх ёстой бөгөөд өөрөө Бурханыг эрж хайж, ярилцахаар эрэлхийлэх ёстой. Ийм үед чи хэдий чинээ идэвхгүй байна, төдий чинээ сөрөг болж, ухарч буцахад улам амархан болно. Чи чиг үүргээ биелүүлэх шаардлагатай үед тэрийгээ сайн биелүүлдэггүй хэдий ч чадах бүхнээ хийж, Бурханыг хайрлах хайраараа л хийдэг; бусад хүмүүс юу хэлэх нь хамаагүй, тэд чамайг сайн хийсэн, муу хийсэн гэх нь хамаагүй, Бурханы өмнөөс үйлдэж байгаа учраас санаа зорилго чинь зөв байдаг бөгөөд чи өөрийгөө зөвтгөдөггүй. Бусад хүн чамайг буруугаар ойлгох үед чи Бурханд залбирч: “Өө Бурхан минь! Бусад хүн намайг тэвчээсэй, надад сайн хандаасай гэж би гуйхгүй, намайг ойлгож, сайшаагаасай ч гэж гуйхгүй. Би зүрх сэтгэлээрээ Таныг хайрлаж чаддаг, сэтгэл минь амгалан, мөс чанар минь сэвгүй байгаасай л гэж гуйж байна. Бусад хүн намайг сайшааж, хүндлээсэй гэж би гуйхгүй; би зүрх сэтгэлээсээ Таныг сэтгэл хангалуун байлгах л гэж чармайж, чадах бүхнээ хийж үүргээ гүйцэтгэдэг; хэдийгээр би мулгуу, тэнэг, муу хэв чанартай, сохор боловч Таныг хайр татам гэдгийг мэднэ, байгаа бүхнээ Танд зориулахад би бэлэн байна” хэмээн хэлж чадна. Чамайг ингэж залбирмагц Бурханыг гэсэн хайр чинь бий болж, зүрх сэтгэл чинь илүү уужирна. Бурханыг гэх хайрыг хэрэгжүүлнэ гэдэг энэ юм. Туршлагажихын хэрээр чи хоёронтоо бүтэлгүйтэвч, нэгэнтээ амжилт олно, эсвэл таван удаа бүтэлгүйтэвч, хоёр удаа амжилт олно, ийнхүү туршлагажихдаа чи бүтэлгүйтлийн дундаас л Бурханы хайр татам байдлыг олж харж, чамд юу дутагдаж байгааг илрүүлж чадна. Дараагийн удаа ийм нөхцөл байдалд орох үедээ чи өөртөө сэрэмжлүүлж, алхмаа хязгаарлаж, илүү ойр ойрхон залбирах ёстой. Ийм нөхцөл байдалд амжилт олох чадвараа чи аажмаар хөгжүүлнэ. Ингэвэл залбирал чинь үр дүнтэй болжээ. Энэ удаад амжилт олсноо хараад чи дотроо баярлаж, залбирах үедээ Бурханыг мэдрэн, Ариун Сүнс дэргэдээс чинь холдоогүй гэдгийг мэдэрч чадна—тэр үед л Бурхан чиний дотор хэрхэн ажилладгийг чи мэднэ. Ингэж хэрэгжүүлэх нь чамд туршлагажих замыг олж өгнө. Хэрвээ үнэнийг хэрэгжүүлдэггүй бол Ариун Сүнс чиний дотор байхгүй байх болно. Харин чи үнэнийг хэрэгжүүлбэл аливаа зүйлтэй тулгарахдаа дотроо шархлах боловч Ариун Сүнс дараа нь чамтай хамт байх бөгөөд залбирах үедээ Бурхан байгааг мэдэрч, Бурханы үгийг хэрэгжүүлэх тэнхээтэй байж, ах эгч нартайгаа ярилцах үед мөс чанарыг чинь

шаналгах юу ч байхгүй, амар амгалан санагдаж, ийм маягаар чи хийсэн зүйлээ ил болгож чадна. Бусад хүн юу гэж хэлэх нь хамаагүй, чи Бурхантай хэвийн харилцаатай байж чадах бөгөөд бусдад хязгаарлагдалгүй, бүх зүйлийг даван гарна. Үүгээрээ чи Бурханы үгийн хэрэгжүүлэлт үр дүнтэй байсныг харуулна.

Бурханы цэвэршүүлэлт хэдий чинээ их байна, хүмүүсийн зүрх сэтгэл төдий чинээ Бурханыг хайрлаж чаддаг. Зүрх сэтгэл дэх шаналал нь тэдний аминд ач тустай бөгөөд Бурханы өмнө тэд улам амар амгалан, Бурхантай харилцах харилцаа нь илүү дотно болж, Бурханы дээдийн дээд хайр, дээдийн дээд авралыг улам сайн харж чаддаг. Петр олон зуун удаа цэвэршүүлэлт туулж, Иов хэд хэдэн шалгалт туулсан. Бурханаар төгс болгуулахыг хүсэж байвал та нар ч гэсэн олон зуун удаа цэвэршүүлэлт туулах ёстой; та нар энэ үйл явцыг туулж, энэ алхамд найдаж байж л Бурханы хүслийг хангаж, Бурханаар төгс болгуулж чадна. Цэвэршүүлэлт бол Бурхан хүмүүсийг төгс болгох шилдэг арга юм; цэвэршүүлэлт болон гашуун шалгалтууд л хүмүүсийн зүрх сэтгэл дэх Бурханыг гэсэн жинхэнэ хайрыг гаргаж ирж чадна. Бэрхшээл үгүй бол Бурханыг гэх жинхэнэ хайр хүмүүст дутагддаг; тэднийг дотроос нь туршиж, цэвэршүүлэлт үнэхээр туулуулахгүй бол зүрх сэтгэл нь үргэлж хаа нэгтээ гадна байх болно. Тодорхой хэмжээнд цэвэршүүлэгдсэнээр чи өөрийн сул тал, хүндрэл бэрхшээлийг олж харж, хэр их дутагдалтай гэдгээ, тулгарсан олон асуудлыг даван гарах чадваргүй гэдгээ, дуулгаваргүй байдал чинь хэчнээн их болохоо олж харна. Шалгалтын үеэр л хүмүүс бодит байдлаа үнэнээр нь мэдэж авч чаддаг бөгөөд шалгалтын улмаас хүмүүс илүү сайн төгс болгуулж чаддаг.

Амьдралдаа Петр олон зуун удаа цэвэршүүлэлт туулж, олон хүнд сорилтыг амссан. Энэхүү цэвэршүүлэлт Бурханыг хайрлах дээдийн дээд хайрынх нь суурь, бүхий л амьдралынх нь хамгийн чухал туршлага болсон юм. Тэр дээдийн дээд хайраар Бурханыг хайрлаж чадсан нь нэг талаараа Бурханыг хайрлая гэсэн шийдвэрээс нь болсон; гэхдээ үүнээс ч илүүтэйгээр түүний туулсан цэвэршүүлэлт болон зовлонгоос болсон юм. Энэ зовлон нь Бурханыг хайрлах замд түүний хөтөч болж, хамгийн дурсамжтай зүйл нь болсон билээ. Хэрвээ хүмүүс Бурханыг хайрлахдаа цэвэршүүлэлтийн шаналлыг амсахгүй бол хайр нь өө сэвээр дүүрэн, өөрийн дураар хайраа сонгодог; иймэрхүү хайр Сатаны санаагаар дүүрэн байдаг бөгөөд Бурханы хүслийг хангаж огт чаддаггүй. Бурханыг хайрлая гэж шийдэх нь Бурханыг үнэхээр хайрлахтай адилгүй. Сэтгэл дотроо тэд Бурханыг хайрлаж, Бурханыг хангалуун байлгахыг л бодож, бодол санаа нь хүний ямар ч санааг агуулаагүй мэт, бүхэлдээ Бурханы төлөө байдаг мэт боловч бодол санааг нь Бурханы өмнө аваачихад Бурхан сайшааж ерөөдөггүй. Хүмүүс бүх үнэнийг бүрэн ойлгож, бүгдийг нь мэдэж авсан үед ч гэсэн үүнийг Бурханыг хайрлаж буйн шинж, энэ хүмүүс Бурханыг үнэхээр хайрладаг гэж хэлж болохгүй. Хүмүүс олон үнэнийг ойлголоо ч гэсэн цэвэршүүлэлтийг туулахгүйгээр эдгээр үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг; цэвэршүүлэлтийн үеэр л хүмүүс эдгээр үнэний бодит утга учрыг

ойлгож, тэр үед л эдгээрийн дотоод утга учрыг жинхэнээсээ үнэлж чаддаг. Тэр үед дахин оролдох үедээ тэд үнэнийг зүй зохистойгоор, Бурханы хүслийн дагуу хэрэгжүүлж чаддаг; тэр үед хүний санаа бодол нь цөөрч, завхрал нь багасаж, сэтгэл хөдлөл нь багасдаг; тэр үед л хэрэгжүүлэлт нь Бурханыг хайрлах хайрын жинхэнэ илэрхийлэл байдаг. Зүгээр нэг амаараа хүлээн зөвшөөрч, оюун санаагаараа хүссэнээр Бурханыг хайрлах үнэний үр дүнд хүрдэггүй, мөн тэр үнэнийг зүгээр нэг ойлгосноор ч хүрч чадахгүй. Хүмүүс төлөөс төлж, цэвэршүүлэлтийн үеэр илүү их гашуун зовлон амсах шаардлагатай бөгөөд тэгсэн цагт л хайр нь ариун болж, Бурханы зүрх сэтгэлийн дагуу болдог. Өөрийг нь хайрлахыг хүнээс шаардахдаа Бурхан хүсэл тэмүүлэл юм уу хүслээ ашиглан Өөрийг нь хайрлахыг хүнээс шаарддаггүй; Түүнд үйлчлэхийн тулд үнэнийг ашиглаж, үнэнч байснаар л хүн Түүнийг үнэхээр хайрлаж чадна. Гэвч хүн завхрал дунд амьдардаг учир Бурханд үйлчлэхдээ үнэнч байж, үнэнийг ашиглах чадваргүй байдаг. Хүн нэг бол Бурханыг гэсэн хэтэрхий их оргилсон тэмүүлэлтэй, эсвэл хэтэрхий хүйтэн хөндий, хайхрамжгүй байдаг; нэг бол Бурханыг туйлаас хайрлаж, эсвэл туйлын их үзэн яддаг. Завхрал дунд амьдардаг хүмүүс үргэлж энэ хоёр туйлын хооронд, хүсэл зоригоороо амьдардаг ч өөрсдийнх нь зөв гэдэгт итгэдэг. Хэдийгээр Би үүнийг ахин дахин дурдсан ч хүмүүс үүнийг нухацтайгаар авч үзэж чаддаггүй, ач холбогдлыг нь бүрэн ойлгож чаддаггүй тул өөрийгөө хуурсан итгэл, дур зоргоороо Бурханыг хайрлах хайрын төөрөгдөл дунд амьдардаг. Түүхийн туршид хүн төрөлхтөн хөгжиж, эрин үе өнгөрөхийн хэрээр хүнд тавих Бурханы шаардлага улам өндөрсөж, Өөрт нь үнэмлэхүй хандахыг хүнээс улам бүр шаардах болсон. Гэсэн ч Бурханы талаарх хүний мэдлэг улам бүр тодорхойгүй, хийсвэр болж, Бурханыг хайрлах хайр нь үүнийг даган улам бүр цэвэр ариун бус болсон. Сатан хүнийг улам гүн гүнзгий завхруулсан тул хүний байдал болон хийдэг бүхэн нь Бурханы хүсэлтэй улам их зөрчилддөг. Улам их, улам агуу авралын ажил хийхийг энэ нь Бурханаас шаарддаг. Бурханд тавих хүний шаардлага улам хатуу чанд болж, Бурханыг хайрлах хайр нь улам багассаар байна. Хүмүүс дуулгаваргүйгээр, үнэнгүй, хүн чанаргүй амьдралаар амьдардаг; тэд Бурханыг өчүүхэн төдий ч хайрладаггүйгээр үл барам, дуулгаваргүй байдал, эсэргүүцлээр дүүрэн байдаг. Тэд өөрсдийгөө Бурханыг туйлаас хайрлаж, чадлынхаа хэрээр нийцтэй байдаг гэж боддог боловч Бурхан тэгж үздэггүй. Бурханыг гэх хүний хайр хэчнээн бохир болох нь Бурханд тун тодорхой байдаг бөгөөд зусардлаас нь болж хүний талаарх бодлоо хэзээ ч өөрчлөөгүй, үнэнч байдлаас нь үүдэн хүний сайн санааг хэзээ ч хариулаагүй. Хүнээс ялгаатай нь Бурхан ялгаж салгах чадвартай: Хэн Өөрийг нь үнэхээр хайрладаг, хайрладаггүйг Тэр мэддэг бөгөөд хүний түр зуурын хөөрлөөс болж зүрх сэтгэл нь дүрэлзэж, ухаанаа алдалгүй, харин мөн чанар болон зан авирынх нь дагуу хүнд ханддаг. Эцсийн эцэст Бурхан бол Бурхан бөгөөд Тэр Өөрийн гэсэн эрхэм чанар, мэдлэг ухаантай; хүн эцсийн эцэст хүн бөгөөд үнэнтэй зөрчилддөг хүний хайраас болж Бурханы толгой эргэхгүй. Харин эсрэгээрээ, Тэр хүний хийдэг бүхэнд зүй зохистой ханддаг.

Хүний байдал болон Түүнд хандах хүний хандлагатай нүүр тулаад Бурхан шинэ ажил хийж, Өөрийнхөө талаар мэдлэгтэй, бас Өөртөө дуулгавартай болгож, хайрладаг, гэрчлэл хийдэг болгосон. Иймээс хүн Бурханы цэвэршүүлэлт төдийгүй шүүлт, харьцалт, засалтыг туулах ёстой, ингэхгүйгээр хүн Бурханыг хэзээ ч мэдэхгүй бөгөөд Түүнийг үнэхээр хайрлаж, Түүнд гэрчлэл хийж хэзээ ч чадахгүй. Бурхан хүнийг зүгээр л өрөөсгөл үр дүнгийн төлөө бус, харин олон талт үр дүнгийн төлөө цэвэршүүлдэг. Ингэж л Бурхан үнэнийг эрж хайх хүсэлтэй хүмүүсийн шийдвэр, хайрыг төгс болгохын тулд тэдэн дээр цэвэршүүлэлтийн ажил хийдэг. Үнэнийг эрж хайхыг хүсдэг, Бурханыг хүсэмжилдэг хүмүүст ийм цэвэршүүлэлтээс илүү утга учиртай, ач тустай зүйл гэж үгүй. Бурхан бол эцсийн эцэст Бурхан учир Бурханы зан чанарыг хүн мэдэж, ойлгоход амар биш. Эцсийн эцэст Бурхан хүнийх шиг зан чанартай байх боломжгүй учраас Түүний зан чанарыг мэднэ гэдэг хүнд амаргүй байдаг. Үнэн хүнд төрөлхөөс байдаггүй бөгөөд Сатаны завхруулсан хүмүүс үүнийг ойлгоход амаргүй байдаг; хүнд үнэн, үнэнийг хэрэгжүүлэх шийдэмгий зан байдаггүйн дээр зовж, цэвэршүүлэгдэж, шүүгдэхгүй бол шийдэмгий зан нь хэзээ ч төгс болохгүй. Цэвэршүүлэлт нь бүх хүний хувьд шаналгаатай, хүлээн зөвшөөрөхөд маш хэцүү байдаг хэдий ч цэвэршүүлэлтийн үеэр Бурхан зөвт зан чанараа хүнд ил болгож, хүнд тавих шаардлагаа ил тод болгож, хүнийг улам их гэгээрэл, улам бодитой засалт, харьцалтаар хангадаг; Тэрээр баримт, үнэн хоёрыг харьцуулах замаар хүнд өөрийнх нь талаар болон үнэний талаар илүү их мэдлэг өгч, Бурханы хүслийн талаар улам их ойлгуулж, улмаар Бурханыг илүү жинхэнэ, цэвэр ариунаар хайрлах боломжийг олгодог. Цэвэршүүлэлт явуулах Бурханы зорилго ийм юм. Хүнд Бурханы хийдэг бүх ажил нь өөрийн гэсэн зорилго, ач холбогдолтой байдаг; Бурхан утга учиргүй ажил хийдэггүй, хүнд ашиггүй ажил ч хийдэггүй. Цэвэршүүлэлт нь хүмүүсийг Бурханы дэргэдээс холдуулна гэсэн үг биш, тэднийг тамд устгана гэсэн ч үг биш. Харин цэвэршүүлэлтийн үеэр хүний зан чанар, санаа зорилго, хуучин үзэл бодлыг өөрчилж, Бурханыг гэх хайрыг нь өөрчилж, хүний бүхий л амьдралыг өөрчилнө гэсэн үг юм. Цэвэршүүлэлт бол хүнийг турших жинхэнэ туршилт, бодит сургалтын нэг хэлбэр бөгөөд цэвэршүүлэлтийн үеэр л хүний хайр төрөлх үүргээ гүйцэтгэж чадна.

БУРХАНЫГ ХАЙРЛАДАГ ХҮМҮҮС ТҮҮНИЙ ГЭРЭЛД ҮҮРД АМЬДАРНА

Ихэнх хүмүүсийн Бурханд итгэх итгэлийн мөн чанар нь шашны итгэл үнэмшил байдаг: Тэд Бурханыг хайрлах чадваргүй, Бурханыг робот шиг л дагаж чаддаг, Бурханыг үнэхээр хүсэмжилж, эрхэмлэн хайрлаж чаддаггүй. Тэд ердөө л Бурханыг чимээгүйхэн дагадаг. Олон хүн Бурханд итгэдэг ч Түүнийг хайрладаг хүн тун цөөн; тэд гай гамшгаас айдаг учраас л Бурханыг “хүндэлдэг”, эсвэл Бурхан өндөр дээд

агаад хүчирхэг учраас л тэд Түүнийг “биширдэг”—гэхдээ тэдний хүндлэл, бишрэлд ямар ч хайр, жинхэнээсээ хүсэмжлэх сэтгэл байдаггүй. Тэд өөрсдийн туршлагаар үнэний өчүүхэн хэсэг, эсвэл чухал бус зарим нууцыг эрж хайдаг. Ихэнх хүмүүс зүгээр л дагаж, сиймхий тааруулж ерөөл хүртэх гэж оролддог; тэд үнэнийг эрж хайдаггүй, Бурханы ерөөлийг хүртэхийн тулд Бурханд үнэхээр дуулгавартай ч байдаггүй. Бүх хүний Бурханд итгэх итгэлийн амьдрал нь учир утгагүй, үнэ цэнгүй бөгөөд энэ амьдралд өөрсдийнх нь хувийн анхаардаг зүйл, эрэл хайгуул байдаг; тэд Бурханыг хайрлахын тулд биш, харин ерөөгдөхийн тулд Бурханд итгэдэг. Олон хүн хүссэнээрээ авирлаж, хүссэн бүхнээ хийж, Бурханы ашиг сонирхлыг болон өөрсдийнх нь хийж байгаа зүйл Бурханы хүсэлд нийцэж байгаа эсэхийг хэзээ ч анхаарч үздэггүй. Ийм хүмүүс Бурханыг хайрлах нь байтугай жинхэнэ итгэлд ч хүрч чаддаггүй. Бурханы мөн чанар бол зөвхөн хүнээр итгүүлэх биш; бас хүнээр хайрлуулах явдал юм. Гэвч Бурханд итгэдэг олон хүн энэ “нууцыг” олж мэдэх чадваргүй байдаг. Хүмүүс Бурханыг хайрлаж зүрхэлдэггүй, Түүнийг хайрлах гэж хичээдэг ч үгүй. Бурханд хайр татам зүйл маш олон байгааг тэд хэзээ ч олж мэдээгүй; Бурхан бол хүнийг хайрладаг Бурхан, Тэр бол хүнээр хайрлуулах ёстой Бурхан гэдгийг тэд хэзээ ч олж мэдээгүй. Бурханы хайр татам байдал Түүний ажлаас илэрдэг: Бурханы ажлыг туулсан үедээ л хүмүүс хайр татам байдлыг нь олж мэдэж, бодит туршлагаараа л Бурханы хайр татам байдлыг ойлгож чаддаг бөгөөд бодит амьдрал дээр ажиглахгүйгээр хэн ч Бурханы хайр татам байдлыг олж мэдэж чадахгүй. Бурханд хайр татам зүйл зөндөө бий боловч Түүнтэй бодитоор харилцахгүйгээр хүмүүс үүнийг олж мэдэж чадахгүй. Өөрөөр хэлбэл, хэрвээ Бурхан махбод болоогүй бол хүмүүс бодитоор Түүнтэй харилцаж чадахгүй байх байсан. Хэрэв тэд бодитоор Түүнтэй харилцах чадахгүй байсан бол Түүний ажлыг бас мэдэрч чадахгүй байх байсан—иймээс Бурханыг хайрлах тэдний хайр ихээхэн худал хуурмаг болон төсөөллөөр сэвтэх байлаа. Тэнгэр дэх Бурханыг хайрлах нь газар дээрх Бурханыг хайрлахтай адил бодитой биш юм, учир нь тэнгэр дэх Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг өөрсдийн нүдээр харж, биеэр туулсан зүйлээс илүүтэйгээр төсөөлөл дээр нь үндэслэн бий болсон байдаг. Бурхан газар дээр ирэх үед хүмүүс Түүний бодит үйл хэрэг, хайр татам байдлыг харж чаддагийн дээр тэд Түүний бодитой болоод хэвийн зан чанарыг бүгдийг нь харж чадна, энэ бүхэн нь тэнгэр дэх Бурханы талаарх мэдлэгээс хэдэн мянга дахин илүү бодитой юм. Тэнгэр дэх Бурханыг хүмүүс хэр их хайрладгаас үл хамааран, энэ хайранд бодитой зүйл юу ч байхгүй, хүмүүний санаагаар дүүрэн байдаг. Газар дэлхий дээрх Бурханыг хайрлах тэдний хайр хэчнээн бага байх нь хамаагүй, энэ хайр бол жинхэнэ; өчүүхэн бага байлаа ч гэсэн, жинхэнэ юм. Бурхан бодитой ажлаар дамжуулан хүмүүст Өөрийгөө мэдүүлдэг бөгөөд уг мэдлэгээр дамжуулан тэдний хайрыг олж авдаг. Яг л Петр шиг: Хэрвээ тэр Есүстэй хамт амьдраагүй бол түүний хувьд Есүсийг эрхэмлэн хайрлах боломжгүй байх байсан. Есүсийг гэх үнэнч сэтгэл нь мөн л Есүстэй хамт байснаас үүссэн. Өөрийгөө хүнээр хайрлуулахын тулд Бурхан

хүмүүсийн дунд ирж, хүнтэй хамт амьдардаг бөгөөд хүмүүст харуулж, мэдрүүлдэг бүхэн нь Бурханы бодит байдал юм.

Бурхан бодит байдал болон бий болсон баримтыг ашиглан хүмүүсийг төгс болгодог; Бурханы үг нь хүмүүсийг төгс болгох Түүний ажлын нэг хэсгийг биелүүлдэг бөгөөд энэ бол удирдамжийн ажил, зам нээх ажил юм. Өөрөөр хэлбэл, Бурханы үгээс чи хэрэгжүүлэлтийн зам, үзэгдлийн талаарх мэдлэгийг олох ёстой. Эдгээр зүйлийг ойлгосноор, хүн бодитоор хэрэгжүүлэх зам, үзэгдэлтэй болох болно, мөн Бурханы үгээр дамжуулан гэгээрлийг олж чадах бөгөөд эдгээр зүйл Бурханаас ирдэг гэдгийг ойлгож, ихээхэн ялган таних чадвартай болно. Ойлгосныхоо дараа хүн энэ бодит байдал руу даруйхан орж, бодит амьдралдаа Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд Бурханы үгийг ашиглах ёстой. Бурхан чамайг бүх зүйл дээр залж чиглүүлж, хэрэгжүүлэх замыг чамд өгч, Өөрийгөө маш хайр татам гэдгийг чамд мэдрүүлэн, мөн чамд хийдэг Өөрийнх нь ажлын алхам бүр чамайг төгс болгохын тулд байдаг гэдгийг чамд харуулна. Хэрвээ чи Бурханы хайрыг харахыг хүсвэл, хэрвээ чи Бурханы хайрыг үнэхээр мэдэрмээр байвал бодит байдал руу гүн орж, бодит амьдралд гүн орж Бурханы хийдэг бүхэн нь хайр, аврал юм гэдгийг, мөн хүмүүсийн бохир зүйлийг нь хаяулж, тэдэнд байдаг, Бурханы хүслийг хангаж чадахгүй зүйлсийг нь цэвэршүүлэхийн төлөө Бурхан бүхнийг хийдэг гэдгийг харах ёстой. Бурхан үг ашиглаж хүнийг хангадаг; хүмүүсээр туулуулах гэж бодит амьдралын нөхцөл байдлыг бий болгодог, хэрвээ хүмүүс Бурханы үгээс ихийг идэж, уувал тэдгээрийг бодитоор хэрэгжүүлэх үед, Бурханы олон үгийг ашиглан өөрсдийн амьдрал дахь бүх бэрхшээлийг шийдвэрлэж чадна. Өөрөөр хэлбэл, бодит байдалд гүн орохын тулд чамд Бурханы үг байх ёстой; хэрвээ чи Бурханы үгийг идэж уудаггүй, Бурханы ажил чамд байдаггүй бол бодит амьдрал дээр чамд зам байхгүй байх болно. Хэрвээ чи Бурханы үгийг хэзээ ч идэж уухгүй бол ямар нэгэн зүйл тохиолдоход чи сандарч будилна. Чи Бурханыг хайрлах ёстой гэдгээ л мэддэг боловч ямар ч ялгах чадваргүй, хэрэгжүүлэх ямар ч замгүй байдаг; чи төөрөлдөж, будилдаг, махан биеийг сэтгэл хангалуун байлгаснаар Бурханыг сэтгэл хангалуун болгож байна гэж хүртэл заримдаа итгэдэг—энэ бүхэн нь Бурханы үгийг идэж уугаагүйн үр дагавар юм. Өөрөөр хэлбэл, хэрвээ чамд Бурханы үгийн тусламж үгүй бөгөөд бодит байдал дунд зөвхөн тэмтчин явж байгаа бол чи үндсэндээ хэрэгжүүлэх замыг олох чадваргүй юм. Иймэрхүү хүмүүс Бурханд итгэх гэдэг нь юу гэсэн үг болохыг зүгээр л ойлгодоггүй, тэр ч бүү хэл Бурханыг хайрлана гэдэг нь юу гэсэн үг болохыг ч ойлгодоггүй. Хэрвээ Бурханы үг чамайг гэгээрүүлж, удирдан чиглүүлж байгааг ашиглан, үргэлж залбирч, судалж, эрж хайж, үүгээрээ дамжуулан юуг хэрэгжүүлэх учиртайгаа мэдэж, Ариун Сүнс ажиллах боломжийг олж, Бурхантай үнэхээр хамтран ажиллаж, төөрч будилдаггүй бол бодит амьдрал дээр замтай болж, Бурханыг үнэхээр сэтгэл хангалуун байлгах болно. Бурханыг сэтгэл хангалуун болгох үед Бурхан чамайг дотроос чинь удирдан чиглүүлж, Бурхан чамайг онцгойлон ерөөхөд чамд баяр хөөр төрнө: Бурханыг сэтгэл хангалуун

болгосондоо чи тун их баярлан бахдаж, дотор чинь үлэмж цэлмэсэн санагдаж зүрх, сэтгэлдээ хиргүй тунгалаг, амар амгалан болж, мөс чанар чинь тайвширч, буруушаалтаас ангид болж, ах, эгч нараа хараад чамд таатай санагдана. Бурханы хайрыг эдлэх гэдэг нь энэ бөгөөд зөвхөн энэ л Бурханыг үнэхээр таашааж байгаа хэрэг билээ. Хүмүүс туршлагаар дамжуулан Бурханы хайрыг эдэлдэг: Бэрхшээлийг туулж, үнэнийг хэрэгжүүлж туршлагажсанаар тэд Бурханы ерөөлийг олж авдаг. Бурхан чамд үнэхээр хайртай, Бурхан үнэхээр хүмүүсийн төлөө өндөр төлөөс төлж, Тэр тэвчээртэйгээр, сайхан сэтгэлээр маш олон үг хэлсэн бөгөөд үргэлж хүмүүсийг авардаг гэж л гагцхүү чи хэлэх юм бол эдгээр үгийг хэлж байгаа чинь Бурханыг таашаахын зөвхөн нэг тал нь юм. Гэхдээ илүү их бодитой таашаал нь хүмүүс бодит амьдралдаа үнэнийг хэрэгжүүлэх явдал бөгөөд үүний дараа тэдний зүрх сэтгэл нь амар амгалан, хиргүй тунгалаг болж, сэтгэл нь ихэд хөдөлж, Бурхан бол хамгийн хайр татам гэдгийг мэдэрдэг. Чиний төлсөн төлөөс туйлын хангалттай байсныг чи мэдэрнэ. Хичээл зүтгэлдээ асар их төлөөс төлснөөр дотор чинь үлэмж цэлмэх болно: Чи Бурханы хайрыг үнэхээр эдэлж байгаагаа мэдэрч, Бурхан хүмүүст авралын ажлаа хийчихсэнийг, хүмүүсийг цэвэршүүлдэг нь тэднийг ариусгахын төлөө байдаг гэдгийг, Өөрийг нь үнэхээр хайрладаг эсэхийг туршихын тулд Бурхан хүмүүсийг шалгадаг гэдгийг ойлгоно. Хэрвээ чи үргэлж ийм маягаар үнэнийг хэрэгжүүлбэл аажмаар Бурханы олон ажлын талаар тодорхой мэдлэгтэй болох ба тэр үед чиний өмнө байгаа Бурханы үг болор мэт тунгалаг болохыг мэдэрнэ. Хэрвээ чи олон үнэнийг тодорхой ойлгож чадвал, бүх хэрэг явдлыг хэрэгжүүлэхэд амархан, аливаа асуудал, аливаа сорилтыг давж чадна гэдгээ мэдэрч, мөн чиний хувьд юу ч асуудал биш гэдгийг хараад чи маш эрх чөлөөтэй болно. Энэ мөчид чи Бурханы хайрыг эдэлж, Бурханы жинхэнэ хайр чам дээр ирсэн байх болно. Үзэгдэлтэй, үнэнтэй, мэдлэгтэй агаад Өөрийг нь үнэхээр хайрладаг хүмүүсийг Бурхан ерөөдөг. Хэрвээ хүмүүс Бурханы хайрыг харахыг хүсвэл үнэнийг бодит амьдралд хэрэгжүүлэх ёстой, тэд Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд зовлон шаналлыг туулж, хайрладаг зүйлсээ хаяхад бэлэн байх ёстой бөгөөд нүдэндээ нулимстай байсан ч Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чадсаар байх ёстой. Ийм маягаар, Бурхан гарцаагүй чамайг ерөөнө, хэрвээ чи иймэрхүү бэрхшээлийг туулбал үүнийг Ариун Сүнсний ажил дагалдана. Бодит амьдралаар дамжуулан, Бурханы үгийг туулснаар хүмүүс Бурханы хайр татам байдлыг харж чаддагийн дээр Бурханы хайрыг амталсан л бол Бурханыг үнэхээр хайрлаж чадна.

Бурханыг хайрладаг хүмүүс бол үнэнийг хайрладаг хүмүүс бөгөөд үнэнийг хайрладаг хүмүүс үнэнийг хэрэгжүүлэх тусмаа улам их үнэнтэй болдог; үнэнийг хэрэгжүүлэх тусмаа Бурханы хайрыг төдий чинээ хүртдэг; үнэнийг хэрэгжүүлэх тусмаа Бурханаар төдий чинээ ерөөгддөг. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлбэл яг л Петр Бурханыг мэдэж авсантай адилаар чамайг гэх Бурханы хайр чамд аажмаар харуулна: Бурханд тэнгэр, газар болон бүх зүйлийг бүтээх мэргэн ухаан байгаад зогсохгүй, бас хүмүүст бодит ажил хийх мэргэн ухаан бий гэж

Петр хэлсэн. Петр хэлэхдээ, Тэр зөвхөн тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээснийхээ төлөө төдийгүй, цаашлаад хүмүүсийг бүтээх, аврах, төгс болгох, Өөрийн хайрыг хүмүүст өвлүүлэх чадварынхаа улмаас хүмүүсийн хайрыг хүртэх эрхтэй гэсэн. Мөн хүний хайрыг хүртэх эрхтэй маш их зүйл Түүнд байдаг хэмээн Петр хэлсэн. Петр Есүст хэлэхдээ: “Та тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээсэн болохоор л хүмүүсийн хайрыг хүртэх эрхтэй гэж үү? Танд илүү их хайр татам зүйл бий. Та бодит амьдрал дээр үйлдэж, хөдөлдөг, Таны Сүнс сэтгэлийг минь хөдөлгөж, Та намайг сахилгажуулж, зэмлэдэг—эдгээр зүйл чинь хүмүүсийн хайрыг бүр ч илүү хүртэх эрхтэй” гэсэн. Хэрвээ чи Бурханы хайрыг харж, мэдрэхийг хүсвэл, бодит амьдрал дээр эрж хайж, судлах ёстойн дээр махан биеэ хаяхад бэлэн байх хэрэгтэй. Чи ийм шийдвэр гаргах ёстой. Чи залхуурч, махан биеийн зугаа цэнгэлд шуналгүйгээр, махан биеийн төлөө бус харин Бурханы төлөө амьдарч бүх зүйл дээр Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадах шийдэмгий хүн байх ёстой. Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадахгүй үе байж болно. Яагаад гэвэл чи Бурханы хүслийг ойлгодоггүй учраас тэр юм; дараагийн удаа, чамаас илүү их хүчин чармайлт шаардах байсан ч гэсэн чи махан биеийг бус Бурханыг сэтгэл хангалуун байлгах ёстой. Ийм маягаар туршлагажвал чи Бурханыг мэдэж авах болно. Бурхан тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээж чадсан, хүмүүс Түүнийг үнэхээр, бодитоор харж, Түүнтэй бодитоор харилцаж чадаасай гэсэндээ Тэр махбод болсон, Тэр хүмүүсийн дунд алхаж чаддаг, Түүний Сүнс бодит амьдрал дээр хүмүүсийг төгс болгож, Түүний хайр татам байдлыг харж, Түүний сахилгажуулалт, цээрлүүлэлт болон ерөөлийг мэдрэх боломж олгодгийг чи харна. Хэрвээ чи үргэлж ийм маягаар туршлагажвал бодит амьдрал дээр Бурханаас салшгүй байх ба хэзээ нэг өдөр Бурхантай харилцах харилцаа чинь хэвийн байхаа боливол чи зэмлэл хүртэж, гэмшиж чаддаг болно. Бурхантай хэвийн харилцаатай байхдаа чи Бурханыг орхихыг хэзээ ч хүсэхгүй бөгөөд хэрвээ нэг өдөр л Бурхан чамайг орхино гэдгээ хэлбэл чи айж, Бурханд хаягдсанаас үхсэн нь дээр гэж чи хэлнэ. Чамд ийм сэтгэл хөдлөл төрмөгц Бурханыг орхиж чадахгүй гэдгээ чи мэдэрнэ, ийм маягаар чи үндэс суурьтай болж, Бурханы хайрыг жинхэнээр нь эдэлнэ.

Хүмүүс Бурханыг өөрсдийн амь болгох тухай байнга ярьдаг боловч хараахан тийм түвшинд хүртэл туршлагажаагүй байна. Бурхан миний амь, Тэр намайг өдөр бүр залж чиглүүлдэг, би Түүний үгийг өдөр бүр идэж уудаг, Түүнд өдөр бүр залбирдаг, иймээс Тэр миний амь болсон гэж чи зүгээр л хэлдэг. Ингэж хэлдэг хүмүүсийн мэдлэг тун өнгөц байдаг. Олон хүнд ямар ч суурь байдаггүй; Бурханы үгийг тэдэнд суулгасан байдаг боловч ямар нэгэн жимс гарах нь байтугай, соёолоогүй ч гүй байдаг. Өнөөдөр чи ямар хэмжээнд туршлагажсан бэ? Бурхан чамайг энэ хүртэл явтал чинь хүчилсний дараа, одоо л Бурханыг орхиж чадахгүй гэдгээ чи мэдэрдэг. Нэг л өдөр, чамайг тодорхой хэмжээнд туршлагажсан үед Бурхан чамайг явуулахаар боллоо гэхэд чи явж чадахгүй байх болно. Бурхангүйгээр байж чадахгүй гэдгээ чи дотроо үргэлж мэдрэх болно; чи эхнэр,

нөхөр, хүүхэд, гэр бүл, эцэг, эхгүй, махан биеийн зугаа цэнгэлгүйгээр амьдарч чадах ч Бурхангүйгээр байж чадахгүй. Бурхангүй байх нь амиа алдаж байгаатай адил байх болно; чи Бурхангүйгээр амьдарч чадахгүй. Чи энэ түвшинд хүртэл туршлагажихад Бурханд итгэх итгэлдээ хүссэн үр дүнд хүрсэн байх болно, ийм маягаар Бурхан чиний амь болж, чиний оршин тогтнолын суурь болсон байх бөгөөд чи Бурханыг хэзээ ч дахин орхиж чадахгүй. Чи энэ түвшинд хүртэл туршлагажихдаа Бурханы хайрыг үнэхээр эдэлсэн байх болно, Бурхантай хангалттай дотно харилцаатай болоход, Тэр чиний амь, чиний хайр болж, тэр үед чи Бурханд залбираад ингэж хэлнэ: “Ээ, Бурхан минь! Би Таныг орхиж чадахгүй, Та бол миний амь, би өөр бусад бүх зүйлгүйгээр явж чадна, гэвч Тангүйгээр амьдарч чадахгүй.” Энэ бол хүмүүсийн жинхэнэ биеийн хэмжээ; энэ бол бодит амь. Зарим хүн өнөөдрийг хүртэл албан хүчээр ирж байсан: Тэд хүссэн ч хүсээгүй ч үргэлжлүүлэх ёстой бөгөөд хадны завсар хавчуулагдсан мэт тэдэнд үргэлж санагддаг. Бурхан бол чиний амь, тийм болохоор хэрвээ зүрх сэтгэлээс чинь Бурханыг авчихвал амиа алдахтай адил тийм мэдрэмж чамд төрөх ёстой; Бурхан чиний амь байж, чи Түүнийг орхиж чадахааргүй байх ёстой. Ингэвээс чи Бурханыг үнэхээр бодитоор мэдэрсэн байх болно, тэр үед чи Бурханыг хайрлахдаа жинхэнээсээ хайрлах бөгөөд энэ нь цорын ганц, ариун хайр байна. Нэг л өдөр, амь чинь тодорхой түвшинд хүртэл туршлагажих үед, чи Бурханд залбирч, Бурханы үгийг идэж уух үед Бурханыг дотроо орхиж чадахаа больж, хүссэн ч гэсэн Түүнийг мартаж чадахгүй байх болно. Бурхан чиний амь болсон байна; чи хорвоо ертөнцийг, эхнэр, нөхөр, хүүхдүүдээ мартаж чадах боловч Бурханыг мартахад хэцүү байх болно—мартах боломжгүй, энэ бол чиний жинхэнэ амь бөгөөд Бурханыг гэх жинхэнэ хайр юм. Бурханыг хайрлах хүмүүсийн хайр тодорхой түвшинд хүрэх үед тэдний хайрладаг юу ч Бурханыг гэсэн хайртай нь тэнцэхгүй; Бурханыг гэх тэдний хайр нэн тэргүүнд байдаг. Ийм маягаар бусад бүх зүйлийг орхих чадвартай болж, Бурханы бүх харьцалт, засалтыг хүлээн авахад бэлэн байдаг. Бусад бүх зүйлээс илүү Бурханыг гэх хайрыг олсон үедээ чи бодит байдалд, Бурханы хайранд амьдрах болно.

Бурхан хүмүүсийн амь нь болмогц тэд Бурханыг орхиж чадахаа больдог. Бурханы үйл хэрэг энэ бус уу? Үүнээс илүү гэрчлэл гэж үгүй! Бурхан тодорхой түвшинд хүртэл ажилласан; Тэр хүмүүст үйлчлэл хий, гэсгээлт хүрт, эсвэл үх гэж хэлсэн бөгөөд хүмүүс үүнээс ухраагүй нь Бурханаар байлдан дагуулагдсан гэдгийг харуулдаг. Үнэнтэй хүмүүс бол бодит туршлагаараа гэрчлэлдээ бат зогсож, байр сууриа чанд хадгалж, Бурханы талд хэзээ ч ухрахгүйгээр зогсож, Бурханыг хайрладаг хүмүүстэй хэвийн харилцаатай байж чаддаг, ямар нэг зүйл тохиолдоход Бурханыг бүрэн дуулгавартай дагаж, үхэн үхтлээ Бурханыг дуулгавартай дагаж чаддаг хүмүүс юм. Чиний бодит амьдрал дахь хэрэгжүүлэлт болон илчлэл бол Бурханы гэрчлэл, хүний амьдран харуулдаг Бурханы гэрчлэл, мөн энэ нь Бурханы хайрыг үнэхээр эдлэх билээ; чи энэ түвшинд хүртэл туршлагажсан үедээ үр дүнд хүрэх болно. Чи бодитоор амьдран харуулдаг бөгөөд чиний үйлдэл бүрийг бусад

хүн гайхан биширдэг. Чиний хувцаслалт, гадаад дүр төрх бусдаас ялгарах юмгүй ч чи хамгийн их сүсэг бишрэлтэй амьдралыг амьдран харуулдгийн дээр Бурханы үгийг дамжуулахад Тэр чамайг залж чиглүүлж, гэгээрүүлдэг. Чи өөрийн үгээр Бурханы хүслийг ярьж, бодит байдлыг дамжуулж чадах ба сүнсээр үйлчлэх тухай их зүйлийг ойлгодог. Чи ний нуугүй ярьдаг, төлөв төвшин, шулуун шударга, зөрж сөргөлддөггүй, соёлтой боловсон, ямар нэг зүйл тохиолдоход Бурханы зохицуулалтыг дуулгавартай дагаж, гэрчлэлдээ бат зогсож чаддаг, юутай ч харьцаж байсан биеэ барьж, тайван байдаг. Ийм хүн Бурханы хайрыг үнэхээр харсан байдаг. Зарим хүн залуухан хэр нь ахимаг насны хүмүүс шиг үйлддэг; тэд төлөвшсөн, үнэнийг олж авсан, бусдын хүндлэлийг хүлээсэн байдаг, тэд бол гэрчлэлтэй хүмүүс бөгөөд Бурханы илрэл билээ. Өөрөөр хэлбэл, тэд тодорхой түвшинд хүртэл туршлагажсан үед Бурханы талаар мэдлэг ухаантай болж, гадаад зан чанар нь ч мөн тогтуун болно. Олон хүн үнэнийг хэрэгжүүлж, гэрчлэлдээ бат зогсдоггүй. Ийм хүмүүст Бурханыг гэх хайр, Түүнд хийх гэрчлэл байдаггүй бөгөөд тэд бол Бурханы хамгийн их жигшдэг хүмүүс билээ. Тэд цуглаан дээр Бурханы үгийг уншдаг боловч амьдран харуулдаг зүйл нь Сатан агаад энэ нь Бурханыг шившиглэж, гутааж, доромжилж байгаа хэрэг юм. Ийм хүмүүст Бурханы хайрын өчүүхэн ч шинж тэмдэг байдаггүй, Ариун Сүнсний ажил огт байдаггүй. Иймээс тэдний үг, үйлдэл Сатаныг төлөөлдөг. Хэрвээ зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж тайван амгалан байж, эргэн тойрныхоо хүмүүс, эд зүйлд болон эргэн тойронд чинь юу болж байгаад үргэлж анхаарал тавьдаг бол, мөн чи Бурханы ачаанд санаа тавьж, үргэлж Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэлтэй байдаг бол Бурхан чамайг дандаа дотроос чинь гэгээрүүлнэ. Чуулганд “хянагч” хүмүүс байдаг ба тэд эхлээд бусдын алдаа дутагдлыг ажиглаж, дараа нь хуулбарлаж, дуурайдаг. Тэд ялган салгах чадваргүй, нүглийг үзэн яддаггүй, Сатаны аливаа зүйлийг жигшин зэвүүцдэггүй. Тийм хүмүүс Сатаны зүйлсээр дүүрсэн байдаг бөгөөд эцэстээ Бурханд бүрэн хаягдах болно. Зүрх сэтгэл чинь Бурханы өмнө үргэлж хүндэтгэлтэй байж, үг, үйлдэл чинь боломжийн байх ёстой бөгөөд Бурханыг эсэргүүцэж, гонсойлгохыг хэзээ ч хүсэж болохгүй. Чамд хийсэн Бурханы ажил хий дэмий болохыг чи хэзээ ч хүсэх ёсгүй, чиний туулсан бүх бэрхшээл зовлон, чиний хэрэгжүүлсэн бүхэн талаар өнгөрөхийг зөвшөөрөх ёсгүй. Чи цаашдын замдаа илүү шаргуу ажиллаж, Бурханыг илүү их хайрлахад бэлэн байх ёстой. Үзэгдлийг сууриа болгосон хүмүүс ийм байдаг. Өсөж дэвшихийг эрж хайдаг хүмүүс ийм байдаг.

Хэрвээ хүмүүс Бурханыг хүндлэх сэтгэлээр Бурханд итгэж, Түүний үгийг туулдаг бол тийм хүмүүсээс Бурханы аврал болон Бурханы хайрыг харж болно. Энэ хүмүүс Бурханыг гэрчилж чаддаг; тэд үнэнийг амьдран харуулдаг бөгөөд тэд бас үнэнийг, Бурхан юу болохыг, Бурханы зан чанарыг гэрчилдэг. Тэд Бурханы хайран дунд амьдардаг, Бурханы хайрыг харсан байдаг. Хэрвээ хүмүүс Бурханыг хайрлахыг хүсвэл Бурханы хайр татам байдлыг амсаж, харах ёстой; ингэсэн цагт л Бурханыг хайрлах сэтгэл, Бурханы төлөө өөрийгөө үнэнчээр өгөхийг зоригжуулах

зүрх сэтгэл тэдэнд төрөх болно. Бурхан үг хэллэг, эсвэл төсөөллөөр нь дамжуулан хүмүүсээр Өөрийгөө хайрлуулдаггүй, Өөрийгөө хайрлуулахаар хүмүүсийг албаддаггүй. Харин Тэр өөрсдийнх нь хүслээр тэднээр Өөрийгөө хайрлуулж, Өөрийн ажил, айлдвараараа хайр татам байдлаа харуулснаар Бурханыг хайрлах хайр тэдэнд бий болдог. Зөвхөн ийм маягаар л хүмүүс Бурханд үнэхээр гэрчлэл хийж чадна. Хүмүүс бусдаар шаардуулж, бас түр зуурын сэтгэлийн хөөрлөөс болж Бурханыг хайрладаг юм биш. Тэд Бурханы хайр татам байдлыг, хүмүүсийн хайрлууштай маш их зүйл Түүнд байдгийг харсан учраас, мөн Түүний аврал, мэргэн ухаан, гайхалтай үйл хэргийг харсан учраас Бурханыг хайрладаг—тийм учраас тэд Бурханыг үнэхээр магтаж, хүсэмжилж, Бурханыг олж авахгүйгээр амьдарч чадахгүй юм шиг тийм оргилсон сэтгэл тэдэнд төрдөг. Бурханыг үнэхээр гэрчилдэг хүмүүс яагаад Түүнд цангинасан гэрчлэл хийх чадвартай байдгийн шалтгаан нь тэдний гэрчлэл Бурханыг гэх жинхэнэ мэдлэг болон жинхэнэ хүсэл тэмүүлэлд суурилдагт оршино. Ийм гэрчлэлийг сэтгэл хөдлөлөөр биш, харин Бурхан болон Түүний зан чанарын талаарх мэдлэгийн дагуу хийдэг. Тэд Бурханыг мэдэж авсан учраас Бурханыг гарцаагүй гэрчилж, Бурханыг хүсэмжилдэг бүх хүнд Бурханыг мэдүүлж, Бурханы хайр татам байдал, бодитой байдлын талаар мэддэг байх ёстой гэдгээ мэдэрдэг. Яг л хүмүүсийн Бурханыг хайрлах хайр шиг, тэдний гэрчлэл хар аяндаа бий болдог бөгөөд бодитой, бодит ач холбогдолтой, үнэ цэнтэй байдаг. Энэ нь идэвхгүй, хий хоосон, утгагүй зүйл биш юм. Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүсийн амьдрал хамгийн үнэ цэнтэй, утга учиртай байдаг, зөвхөн тэд л Бурханд үнэхээр итгэдгийн шалтгаан нь энэ хүмүүс Бурханы гэрэлд амьдарч, Бурханы ажил болон удирдлагын төлөө амьдарч чаддагаас болдог. Учир нь тэд харанхуйд биш, харин гэрэлд амьдардаг; тэд утга учиргүй амьдралаар биш, харин Бурханы ерөөсөн амьдралаар амьдардаг. Бурханыг хайрладаг хүмүүс л Бурханыг гэрчлэх чадвартай, зөвхөн тэд л Бурханыг гэрчлэгчид, тэднийг л Бурхан ерөөдөг, зөвхөн тэд л Бурханы амлалтыг хүлээн авах чадвартай юм. Бурханыг хайрладаг хүмүүс нь Бурханы дотнын хүмүүс; тэд бол Бурханы хайрладаг хүмүүс бөгөөд Бурхантай хамт ерөөл эдэлж чадна. Зөвхөн ийм хүмүүс л мөнх амьдарч, зөвхөн тэд л Бурханы хайр халамж, хамгаалалт дор үүрд амьдрах болно. Бурхан хүмүүсээр хайрлуулахын тулд байдаг, Тэрээр бүх хүний хайрыг хүртэх эрхтэй боловч бүх хүн Бурханыг хайрлаж чаддаггүй, мөн бүх хүн Бурханыг гэрчилж, Бурхантай хамт эрх барьж чадахгүй. Тэд Бурханыг гэрчилж, Бурханы ажилд бүхий л хүчин чармайлтаа зориулж чаддаг учраас Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс өөрсдийг нь эсэргүүцэж зүрхлэх хүнгүйгээр тэнгэрийн дор хаа сайгүй алхан явж, газар дээр эрх мэдэл эзэмшиж, Бурханы бүх ард түмнийг захирч чадна. Энэ хүмүүс дэлхийн өнцөг булан бүрээс нэгдэн нийлсэн бөгөөд өөр өөр хэлээр ярьдаг, арьсны өнгө нь өөр боловч оршихуй нь нэгэн адил утга учиртай; тэд бүгд Бурханыг хайрладаг зүрх сэтгэлтэй, бүгд адилхан гэрчлэл хийдэг, адилхан шийдвэртэй, адилхан хүсэлтэй байдаг. Бурханыг хайрладаг хүмүүс дэлхий даяар чөлөөтэй алхаж, Бурханыг гэрчилдэг хүмүүс

орчлон ертөнц даяар аялж чадна. Энэ хүмүүс бол Бурханы хайртай хүмүүс, Бурхан тэднийг ерөөсөн бөгөөд тэд үүрд Түүний гэрэлд амьдрах болно.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТЭД АНХААРДАГ ХҮМҮҮС Л ТӨГС БОЛГУУЛЖ ЧАДНА

Эцсийн өдрүүдэд Өөрийн хийх учиртай ажлыг хийж, үгийн үйлчлэлээ гүйцэтгэхээр Бурхан махбод болсон. Тэрээр Өөрийн зүрх сэтгэлийн дагуух хүмүүсийг төгс болгох зорилготойгоор хүмүүсийн дунд ажиллахаар биечлэн ирсэн юм. Бүтээлийн цаг үеэс өнөөдрийг хүртэл эцсийн өдрүүдэд л Тэр ийм ажил хэрэгжүүлсэн билээ. Зөвхөн эцсийн өдрүүдэд л Бурхан ийм том далайцтай ажил хийхээр бие махбодтой болсон. Хүмүүсийн хувьд даван туулахад хэцүү санагддаг зовлон бэрхшээлийг Тэр туулдаг хэдий ч, мөн агуу Бурхан атлаа эгэл жирийн хүн болох даруу төлөв зантай ч, Түүний ажлын аль ч тал хойшлоогүй, Түүний төлөвлөгөө өчүүхэн төдий ч эмх замбараагүй байдалд автаагүй. Тэр анхдагч төлөвлөгөөнийхөө дагуу ажлаа хийж байна. Энэ удаа бие махбодтой болохын нэг зорилго нь хүмүүсийг байлдан дагуулах, нөгөө нь Өөрийн хайрладаг хүмүүсийг төгс болгох явдал юм. Төгс болгосон хүмүүсээ харахыг Тэр хүсдэг бөгөөд Түүний төгс болгосон хүмүүс Өөрт нь гэрчлэл хийхийг харахыг хүсдэг. Төгс болгуулдаг нь ганц хоёрхон хүн биш. Харин ердөө хэдхэн хүнээс бүрдэх бүлэг юм. Энэ бүлгийн хүмүүс дэлхийн янз бүрийн улс орон, олон янзын үндэстнээс гаралтай. Ийм их ажил хийхийн зорилго нь энэ бүлэг хүмүүсийг олж авах, энэ бүлэг хүмүүсийн Түүнд хийдэг гэрчлэлийг олж авах, тэднээс гарч болох Өөрийн алдрыг авах явдал билээ. Тэр ач холбогдолгүй ажил хийдэггүй, үнэ цэнгүй ажил ч хийдэггүй. Ийм их ажил хийхдээ Бурхан төгс болгохыг хүсдэг бүх хүмүүсээ төгс болгохоор зорьдог гэж хэлж болно. Үүнээс гадуурх чөлөөт цагаараа Тэр муу хүмүүсийг хөөн зайлуулна. Тэрээр муу хүмүүсээс болж энэ асар их ажлыг хийдэггүй; харин ч эсрэгээрээ Өөрөөр нь төгс болгуулах тэр цөөн тооны хүмүүсээс болж бүхнээ өгдөг гэдгийг мэдэж ав. Түүний хийдэг ажил, хэлдэг үг, илчилдэг нууц, Түүний шүүлт, гэсгээлт бүгд тэрхүү цөөн тооны хүмүүсийн төлөө байдаг. Тэрээр муу хүмүүсээс болж махбод болоогүй бөгөөд тэрхүү муу хүмүүс Түүний асар их уур хилэнг бүр ч өдөөдөггүй. Төгс болгуулах хүмүүсээс болж Тэр үнэнийг хэлж, оролтын тухай ярьдаг; тэднээс болж Тэр махбод болсон бөгөөд тэднээс болж амлалт, ерөөлөө хайрладаг. Түүний ярьдаг үнэн, оролт, хүн чанарын амьдрал нь муу хүмүүсийн төлөө ажилладаггүй. Тэр муу хүмүүстэй ярилцахаас зайлсхийхийг хүсэж, үүний оронд төгс болгуулах хүмүүст бүх үнэнийг хайрлахаар эрмэлздэг. Гэсэн хэдий ч одоохондоо Түүний баялгийн заримыг эдлэх боломжийг муу хүмүүст олгохыг Түүний ажил шаарддаг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй, Бурханы сэтгэл хангалуун байлгадаггүй, Түүний ажлыг үймүүлдэг хүмүүс бүгд муу. Тэднийг төгс болгох боломжгүй бөгөөд Бурхан тэднийг жигшиж, голдог. Эсрэгээрээ үнэнийг

хэрэгжүүлдэг, Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаг, өөрсдийгөө бүхэлд нь Бурханы ажилд зарлагаддаг хүмүүс бол Бурханы төгс болгодог хүмүүс юм. Бурханы бүрэн төгс болгохыг хүсдэг хүмүүс бол энэ бүлэг хүмүүсээс өөр хэн ч биш бөгөөд Бурханы хийдэг ажил энэ хүмүүсийн төлөө байдаг. Түүний ярьдаг үнэн нь үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүст чиглэдэг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүстэй Тэр ярьдаггүй. Түүний ярьдаг мэдлэг ухаан, ялган таних чадварын өсөлт нь үнэнийг хэрэгжүүлж чаддаг хүмүүст чиглэдэг. Тэр төгс болгуулах хүмүүсийн талаар ярихдаа энэ хүмүүсийг ярьж байгаа. Ариун Сүнсний ажил үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүст чиглэдэг. Мэргэн ухаан, хүн чанар эзэмших гэх мэт зүйлс үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүст чиглэдэг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс үнэний олон үг сонсож болох боловч угаасаа маш муу, мөн үнэнийг сонирхдоггүй учраас тэдний ойлгодог үнэн нь амийнх нь оролтод өчүүхэн ч үнэ цэнгүй хоосон сургаал, үг үсэг, хоосон онол л байдаг. Тэдний хэн нь ч Бурханд үнэнч биш, тэд бол Бурханыг хардаг боловч Түүнийг олж авч чаддаггүй хүмүүс бөгөөд Бурхан тэднийг бүгдийг нь ялладаг.

Ариун Сүнс хүн бүрийн дотор алхах замтай байдаг бөгөөд хүн бүрд төгс болгуулах боломж олгодог. Сөрөг талаар чинь дамжуулан завхралыг чинь чамд мэдүүлдэг бөгөөд дараа нь сөрөг талыг авч хаяснаар хэрэгжүүлэх замыг чи олно; эдгээр нь бүгд төгс болгуулдаг арга замууд чинь юм. Түүнчлэн, өөрийнхөө доторх зарим эерэг зүйлийн байнгын удирдамж, гэрэлтүүлэлтээр дамжуулан чи идэвх санаачилгатайгаар үүргээ биелүүлж, мэдлэг ухаанаа нэмэгдүүлж, ялган таних чадвартай болно. Нөхцөл байдал чинь сайн байх үед чи Бурханы үгийг уншихыг онцгойлон хүсэж, Бурханд залбирахыг онцгойлон хүсэж, сонсдог номлолуудаа өөрийн байр байдалд хамаатуулан ойлгож чадна. Ийм үед Бурхан чамайг дотроос чинь гэгээрүүлж, гэрэлтүүлэн эерэг талын зарим зүйлийг ухааруулдаг. Ингэж чи эерэг талд төгс болгуулдаг. Сөрөг байдалд чи сул дорой, идэвхгүй байдаг; зүрх сэтгэлд чинь Бурхан байхгүйг мэдэрдэг ч Бурхан чамайг гэрэлтүүлж, хэрэгжүүлэх замаа олоход чинь тусалдаг. Энэ байдлаас гарах нь сөрөг талд төгс болгуулж байгаа хэрэг юм. Бурхан хүнийг эерэг, сөрөг талын аль алинд төгс болгож чаддаг. Энэ нь туршлагажиж чаддаг эсэх, Бурханаар төгс болгуулахыг эрэлхийлдэг эсэхээс чинь хамаардаг. Хэрвээ чи Бурханаар төгс болгуулахыг үнэхээр хичээдэг бол сөрөг зүйл чамд хохирол учруулж чадахгүй, харин илүү бодитой зүйлсийг авчран, дотор чинь дутагдаж байгаа зүйлийг илүү сайн мэдэж чаддаг, бодит байдлаа илүү сайн ухамсарлаж чаддаг болгож, хүнд юу ч байхгүй, хүн юу ч биш гэдгийг харуулдаг; хэрвээ чи шалгалтуудыг туулахгүй бол мэдэхгүй бөгөөд бусдаас дээгүүр, бусад бүх хүнээс илүү юм шиг чамд үргэлж санагдана. Энэ бүхнээр дамжуулан, өмнө нь тохиолдсон бүхнийг Бурхан хийж, Бурхан хамгаалдаг байсныг чи ойлгоно. Шалгалтад орох нь чамайг хайр, итгэлгүй болгож орхидог, чамд залбирал дутагдаж, чи магтан дуу дуулж чадахгүй болдог бөгөөд дунд нь чи нэг л мэдэхэд өөрийгөө мэдэж авдаг. Хүнийг төгс болгодог олон арга барил Бурханд бий. Тэрээр

хүний завхарсан зан чанартай харьцахдаа төрөл бүрийн орчныг хэрэглэж, хүнийг ил болгохын тулд төрөл бүрийн зүйл ашигладаг; нэг талаар Тэр хүнтэй харьцдаг, нөгөө талаар хүнийг ил болгодог, өөр нэг талаар Тэр хүнийг илчилж, хүний зүрх сэтгэлийн гүн дэх “нууцыг” ухан гаргаж, илчлэн, олон байр байдлыг нь илчилснээр, уг чанарыг нь хүнд харуулдаг. Бурхан бодитой гэдгийг хүнд мэдэгдэх гэсэндээ илчлэл, хүнтэй харьцах, хүнийг цэвэршүүлэх, гэсгээх гэх мэт олон арга замаар Бурхан хүнийг төгс болгодог.

Та нарын одоо эрж хайж байгаа юм чинь юу вэ? Бурханаар төгс болгуулах, Бурханыг мэдэх, Бурханыг олж авах, эсвэл магадгүй 90-ээд оны Петрийн хэв маягаар биеэ авч явах, Иовоос ч илүү итгэлтэй байхаар эрж хайх, эсвэл Бурханаар зөв шударга нэгэн гэж дуудуулан, Бурханы сэнтийн өмнө очихоор эрж хайх, эсвэл Бурханыг газар дээр илэрхийлж, Бурханы төлөө хүчтэй, цангинасан гэрчлэл хийж чаддаг болохоор эрж хайх явдал байж магадгүй. Та нар юу ч эрж хайдаг бай, энэ нь бүхэлдээ Бурханаар аврууллахын төлөө байдаг. Чи зөв шударга хүн болохоор хичээдэг ч бай, Петрийн хэв маяг юм уу Иовын итгэлийг эрж хайдаг ч бай, эсвэл Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлдэг ч бай хамаагүй, энэ нь бүгд хүн дээр хийдэг Бурханы ажил юм. Өөрөөр хэлбэл, чи юу ч эрж хайдаг бай, энэ нь бүгд Бурханаар төгс болгуулахын төлөө, Бурханы үгийг туулахын төлөө, Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгахын төлөө байдаг; чи юу ч эрж хайдаг бай, энэ нь бүгд Бурханы хайр татам байдлыг олж мэдэхийн төлөө, тэрслүү зан чанараа хаяж чаддаг болох зорилготойгоор бодит туршлагаар хэрэгжүүлэх замыг хайхын төлөө, дотроо хэвийн байдалд хүрч, Бурханы хүсэлтэй бүрэн нийцэж, зөв хүн болж, хийж байгаа бүхэндээ зөв сэдэлтэй байхын төлөө юм. Чиний хувьд энэ бүх зүйлийг туулж байгаагийн шалтгаан нь Бурханыг мэддэг болж, амийн өсөлтөд хүрэх явдал юм. Хэдийгээр туулж байгаа зүйл чинь Бурханы үг, бодит үйл явдал, түүнчлэн эргэн тойрны чинь хүмүүс, юмс, зүйлс боловч эцэстээ чи Бурханыг мэдэж, Бурханаар төгс болгуулж чаддаг. Зөв шударга хүний замаар алхахаар эрэлхийлэх, эсвэл Бурханы үгийг хэрэгжүүлэхээр эрэлхийлэх нь гүйлтийн зам, харин Бурханыг мэдэж, Бурханаар төгс болгуулах нь зорьсон газар юм. Чи одоо Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлж байсан ч бай, эсвэл Бурханд гэрчлэл хийхээр эрэлхийлж байсан ч бай, бүгд эцсийн дүндээ Бурханыг мэдэхийн төлөө байдаг; энэ нь Түүний чамд хийдэг ажлыг хий дэмий болгохгүйн төлөө байдаг, ингэснээр чи эцэст нь Бурханы бодит байдлыг мэдэж, Түүний агуу байдлыг мэдэж, үүнээс ч илүүтэйгээр Бурханы даруу, нуугдмал байдлыг мэдэж, Бурханы чамд хийдэг асар их хэмжээний ажлыг мэдэж авдаг. Бурхан энэ бохир, завхарсан хүмүүс дээр ажлаа хийж, энэ бүлэг хүмүүсийг төгс болгож чадах түвшинд хүртлээ Өөрийгөө даруу болгосон. Бурхан хүмүүсийн дунд амьдарч идэж, хүмүүсийг хариулж, хүмүүсийг хэрэгцээт зүйлээр нь хангах гэж л махбод болоогүй. Илүү чухал нь Тэр тэсэхийн аргагүй энэ завхарсан хүмүүс дээр аврах, байлдан дагуулах нүсэр их ажлаа хийдэг. Бүх хүн өөрчлөгдөж, шинэчлэгдэж магадгүй гэсэндээ Тэр хамгийн их завхарсан энэ

хүмүүсийг аврахын тулд агуу улаан лууны гол цөмд ирсэн. Бурханы туулж буй энгүй их бэрхшээл зовлон нь бие махбодтой болсон Бурханы туулдаг бэрхшээл зовлон төдийгүй бүхнээс илүүгээр Бурханы Сүнс туйлын их доромжлол амсдаг—Тэр Өөрийгөө маш их даруу болгож, нуудаг болохоор эгэл жирийн хүн болдог. Бурхан хэвийн хүний амьдралтай, хэвийн хүний хэрэгцээтэй гэдгээ хүмүүст харуулах гэж бие махбодтой болж, махбодын хэлбэрийг авсан. Бурхан Өөрийгөө туйлын их даруу болгожээ гэдгийг батлахад энэ хангалттай. Бурханы Сүнс махбодод биеллээ олдог. Түүний Сүнс маш өндөр, агуу хэдий ч Сүнснийхээ ажлыг хийхийн тулд Тэр ердийн, ялихгүй хүний хэлбэртэй болдог. Та бүгдийн хэв чанар, мэдлэг ухаан, эрүүл ухаан, хүн чанар, амьдрал чинь энэ төрлийн Бурханы хайрыг хүлээж авахад үнэхээр тохирохгүй гэдгийг харуулдаг. Та нар өөрсдийнхөө төлөө Бурханаар ийм зовлон туулуулах үнэхээр эрхгүй. Бурхан бол маш агуу. Тэр маш эрхэм дээд, хүмүүс маш дорд хэдий ч Тэр тэдэн дээр ажилласаар байдаг. Хүмүүсийг хангаж, хүмүүстэй ярилцахын тулд Тэр бие махбодтой болоод зогсохгүй бүр хүмүүстэй хамт амьдардаг. Бурхан маш даруу, маш хайр татам. Хэрэв Бурханы хайрыг дурдангуут, Бурханы нигүүлслийг дурдангуут чи асар их магтаал хэлэнгээ нулимс унагадаг бол, хэрэв чи ийм байдалтай байдаг бол Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй болжээ.

Өнөө үед хүмүүсийн эрэл хайгуулд нэг гажуудал байдаг; тэд зөвхөн Бурханыг хайрлаж, Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрэлхийлдэг боловч Бурханы талаар ямар ч мэдлэггүй байдаг бөгөөд өөрсдийн доторх Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг үл ойшоосон. Тэдэнд Бурханы талаарх жинхэнэ мэдлэгийн суурь байдаггүй. Ийм маягаар тэд туршлага нь ахих тусам урам зоригоо алддаг. Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй болохоор эрэлхийлдэг бүх хүн урьд нь сайн байдалтай байгаагүй, сөрөг, сул дорой байдал руу хэлбийж, үргэлж нулимс урсгаж, цөхрөлд автаж, найдвараа алдсан хэдий ч одоо туршлага хуримтлуулахын хэрээр байр байдал нь сайжирдаг. Харьцалт, эвдэлт туулах туршлагын дараа, эсвэл шалгалт, цэвэршүүлтийн тохиолдлыг туулсны дараа тэд ихээхэн ахиц гаргасан. Сөрөг байдлууд буурч, тэдний амь зан чанарт зарим өөрчлөлт гарсан. Илүү их шалгалт туулахын хэрээр тэдний зүрх сэтгэл Бурханыг хайрлаж эхэлдэг. Бурхан хүмүүсийг төгс болгоход дүрэм байдаг бөгөөд чамайг хэрэгжүүлэх замтай болгож, бүх сөрөг байдлаас чинь салгахын тулд Тэрээр чиний хүсүүштэй хэсгийг ашиглан чамайг гэгээрүүлж, сүнсээрээ чөлөөлөгдөхөд чинь тусалж, Түүнийг хайрлах илүү их чадвартай болгодог. Ийм маягаар чи Сатаны завхарсан зан чанарыг хаяж чаддаг. Чи цайлган, нээлттэй байж, өөрийгөө мэдэн, үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг. Бурхан чамайг гарцаагүй ерөөх тул сул дорой, сөрөг байх үед чинь Тэр чамайг хоёр дахин их гэгээрүүлдэг бөгөөд өөрийгөө илүү сайн мэдэж, өөрийнхөө төлөө гэмшихийг илүү их хүсэж, хэрэгжүүлэх учиртай зүйлсээ илүү сайн хэрэгжүүлж чаддаг байхад чинь тусалдаг. Ийм маягаар л зүрх сэтгэл чинь тайван, амгалан байж чаддаг. Бурханыг мэдэхэд ерөнхийдөө анхаарлаа хандуулдаг, өөрийгөө

мэдэхэд болон хэрэгжүүлэлтдээ анхаарал хандуулдаг хүн Бурханы ажил болон Түүний удирдамж, гэгээрлийг олон дахин хүлээн авч чаддаг болно. Хэдийгээр тийм хүн сөрөг байдалд байж болох ч мөс чанарынхаа үйлдэл юм уу Бурханы үгийн гэгээрлээс үүдэн аливааг даруй өөрчилж чаддаг. Хүн өөрийн бодит байдал, Бурханы зан чанар болон ажлыг мэддэг байх үед зан чанарын өөрчлөлтөд үргэлж хүрдэг. Өөрийгөө мэдэж, өөрийгөө нээхийг хүсдэг хүн үнэнийг хэрэгжүүлж чадна. Энэ төрлийн хүн бол Бурханд үнэнч хүн бөгөөд ойлголт нь гүнзгий эсвэл өнгөцхөн, хомсхон эсвэл арвин ямар ч бай, Бурханд үнэнч хүн Бурханы талаар ойлголттой байдаг. Энэ бол Бурханы зөвт байдал бөгөөд хүмүүсийн олж авдаг зүйл; өөрсдийнх нь ололт юм. Бурханы талаар ойлголттой хүн бол үндэс суурьтай, үзэгдэлтэй нэгэн юм. Энэ төрлийн хүн Бурханы махбодын талаар, Бурханы үг, Бурханы ажлын талаар итгэлтэй байдаг. Бурхан хэрхэн ажиллаж, эсвэл ярьдаг, эсвэл бусад хүмүүс хэрхэн үймээн үүсгэдгээс үл хамааран тэр байр сууриндаа бат зогсож, Бурханы төлөө гэрчлэлд зогсож чаддаг. Хүн ийм байх тусмаа өөрийн ойлгодог үнэнийг улам их хэрэгжүүлж чаддаг. Учир нь тэр үргэлж Бурханы үгийг хэрэгжүүлж, Бурханы талаар илүү их ойлголт олж авч, үүрд Бурханы төлөө гэрчлэлд зогсох шийдвэртэй байдаг.

Сүнсэндээ нарийн мэдрэмжтэй байхын тулд ялган таних чадвартай, дуулгавартай байж, аливааг нэвт шувт харах чадвартай байна гэдэг нь ямар нэгэн зүйлтэй тулгармагц Бурханы үг чамайг дотроос чинь гэрэлтүүлж, гэгээрүүлдэг гэсэн үг юм. Энэ бол сүнс нь нарийн мэдрэмжтэй байгаа хэрэг юм. Бурханы хийдэг бүх зүйл хүмүүсийн сүнсийг сэргээхэд туслахын төлөө байдаг. Бурхан яагаад үргэлж хүмүүсийг хөшүүн, мулгуу гэж хэлдэг вэ? Яагаад гэвэл, хүмүүсийн сүнс үхчихсэн бөгөөд тэд сүнсний зүйлсийг огт мэдэхээ байтлаа маш хөшүүн болчихсон. Бурханы ажил бол хүмүүсийн амийг өсгөж, сүнсийг нь амь ороход туслахын төлөө байдаг, ингэснээр хүмүүс сүнсний зүйлсийг нэвт харж чадах бөгөөд зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлаж, Бурханыг сэтгэл хангалуун байлгаж үргэлж чаддаг. Энэ шатанд ирэх нь хүний сүнс сэргэснийг харуулдаг бөгөөд дараагийн удаа ямар нэг зүйлтэй тулгарахдаа тэрээр нэн даруй хариу үйлдэл хийж чадна. Хүн номлолд уриалагхан хандаж, нөхцөл байдалд түргэн хариу үйлдэл үзүүлдэг. Энэ бол сүнсний нарийн мэдрэмжид хүрэх явдал юм. Гадаад үйл явдалд хурдан хариу үйлдэл хийдэг олон хүн байдаг боловч бодит байдалд орох юм уу сүнсний дэлгэрэнгүй зүйлийг дурдмагц хөшүүн, мулгуу болдог. Тэд өөрсөдтэй нь нүүр тулсан үед л ямар нэг зүйл ойлгодог. Энэ бүхэн нь сүнсээрээ хөшүүн, мулгуу байгаагийн, сүнсний зүйлсийн талаар туршлага багатай байгаагийн тэмдэг юм. Зарим хүн сүнсэндээ нарийн мэдрэмжтэй, ялган таних чадвартай байдаг. Тэдний байр байдлыг заасан үгийг сонсмогцоо тэд цаг алдалгүй тэмдэглэж авдаг. Тэд хэрэгжүүлэх зарчмын тухай үг сонсмогцоо тэдгээрийг хүлээн зөвшөөрч, дараагийн туршлагадаа хэрэглэж, улмаар өөрсдийгөө өөрчилж чаддаг. Энэ бол сүнсэндээ нарийн мэдрэмжтэй хүн юм. Тэр яагаад ийм хурдан хариу үйлдэл хийж чаддаг вэ? Яагаад гэвэл, тэр өдөр тутмын амьдралдаа эдгээр зүйлд анхаарлаа төвлөрүүлдэг. Бурханы үгийг

уншихдаа тэд өөрсдийнхөө байр байдлыг харьцуулан шалгаж, өөрсдийгөө эргэцүүлж чаддаг. Нөхөрлөл, номлол сонсож, өөрсдөд нь гэгээрэл, гэрэлтүүлэлт авчирдаг үг сонсохдоо тэд даруй хүлээн авч чаддаг. Энэ нь өлсгөлөн хүнд хоол өгөхтэй ижилхэн; тэд тэр дор нь идэж чаддаг. Өлсөөгүй хүнд хоол өгвөл хариу үйлдэл хийхдээ тийм ч хурдан байдаггүй. Чи Бурханд үргэлж залбирдаг, тэгээд ямар нэгэн зүйлтэй тулгарах үедээ энэ асуудал дээр Бурхан юу шаардаж, чи яаж үйлдэх ёстой байна, тэр даруй хариу үйлдэл хийж чаддаг. Өнгөрсөн удаа Бурхан энэ асуудал дээр чамайг залж чиглүүлсэн; өнөөдөр үүнтэй ижил төрлийн зүйлтэй тулгарах үедээ чи Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгадаг байдлаар хэрхэн хэрэгжүүлэхээ аяндаа мэднэ. Хэрвээ чи үргэлж ийм маягаар хэрэгжүүлж, үргэлж ийм байдлаар туршлагажвал нэгэн цагт чамд энэ нь амархан болно. Бурханы үгийг унших үедээ Бурхан ямар хүний тухай ярьж байгааг, сүнсний ямар нөхцөл байдлын тухай ярьж байгааг чи мэддэг бөгөөд гол зүйлийг нь ухаарч, хэрэгжүүлж чаддаг; энэ нь туршлагажиж чадахыг чинь харуулдаг. Зарим хүн яагаад энэ тал дээр дутагдалтай байдаг вэ? Яагаад гэвэл, тэд хэрэгжүүлэлтийн тал дээр их хүчин чармайлт гаргадаггүй. Хэдийгээр тэд үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг ч үйлчлэлийн нарийн учрын талаарх, амьдралын үнэний нарийн учрын талаарх жинхэнэ мэдлэг ухаан тэдэнд байдаггүй. Ямар нэгэн зүйл тохиолдоход тэд будилдаг. Ийм маягаар, хуурамч эш үзүүлэгч, эсвэл хуурамч элч ирэх үед чи төөрөлдөж магадгүй. Чи Бурханы үг, ажлын талаар үргэлж нөхөрлөх ёстой—ийм маягаар л үнэнийг ойлгож, ялган таних чадвартай болж чадна. Хэрвээ чи үнэнийг ойлгодоггүй бол ялган таних чадваргүй байх болно. Жишээ нь, Бурхан юу ярьдаг, Бурхан хэрхэн ажилладаг, хүмүүст тавьдаг Түүний шаардлага юу болох, чи ямар хүмүүстэй харилцах ёстой, ямар төрлийн хүмүүсийг голох ёстой—чи эдгээр зүйлийн талаар үргэлж нөхөрлөх ёстой. Хэрэв чи Бурханы үгийг үргэлж ийм маягаар туулбал үнэнийг ойлгож, олон зүйлийг нэгд нэггүй ойлгож, бас ялган таних чадвартай болно. Ариун Сүнсний сахилгажуулалт гэж юу вэ, хүний хүслээс төрсөн буруутгал гэж юу вэ, Ариун Сүнсний удирдамж гэж юу вэ, орчны зохицуулалт гэж юу вэ, дотроос Бурханы үг гэгээрүүлэх гэж юу вэ? Хэрэв чи эдгээр зүйлийн талаар тодорхой мэддэггүй бол ялган таних чадвартай болохгүй. Чи Ариун Сүнснээс юу ирдэг, тэрслүү зан чанар гэж юу болох, Бурханы үгийг хэрхэн дуулгавартай дагах, тэрслүү байдлаа хэрхэн хаяхаа мэдэх ёстой; чи эдгээр зүйлийн талаар туршлагаараа ойлгосон бол үндэс суурьтай байх болно; ямар нэгэн зүйл тохиолдоход үүнийг харьцуулах үнэн болон үндэс суурь болох тохиромжтой үзэгдэл чамд байна. Чи хийдэг юм болгондоо зарчимтай байж, үнэний дагуу үйлдэж чадна. Тэгвэл амьдрал чинь Бурханы гэгээрэл, Бурханы ерөөлөөр дүүрнэ. Түүнийг чин сэтгэлээсээ хайдаг эсвэл Түүнийг амьдран харуулдаг, Түүнд гэрчлэл хийдэг ямар ч хүнд Бурхан шударга бус хандахгүй бөгөөд чин сэтгэлээсээ үнэнээр цангаж чаддаг ямар ч хүнийг Тэр хараахгүй. Хэрэв Бурханы үгийг идэж ууж байхдаа чи жинхэнэ байр байдлаа мэдэхэд анхаарал хандуулж, өөрийн хэрэгжүүлэлт болон өөрийн ойлголтод анхаарал хандуулж чаддаг бол

асуудал тулгарах үед гэгээрэл хүлээн авч, бодитой ойлголт олж авна. Тэгвэл чи бүх зүйл дээр хэрэгжүүлэх, ялган таних замтай байх болно. Үнэнтэй хүн мэхлэгдэх шинжгүй, саад учруулах юм уу дэндүүлэн авирлах янзгүй байдаг. Үнэнээс үүдэн тэр хамгаалагддаг, бас үнэнээс үүдэн тэр илүү ойлголт олж авдаг. Үнэнээс үүдэн тэр хэрэгжүүлэх илүү олон замтай болж, Ариун Сүнс өөр дээр нь ажиллах илүү их боломж, төгс болгуулах илүү их боломжийг олж авдаг.

АРИУН СҮНСНИЙ АЖИЛ БА САТАНЫ АЖИЛ

Хүн сүнсний нарийн ширийнийг хэрхэн ойлгож авдаг вэ? Ариун Сүнс хүн дотор хэрхэн ажилладаг вэ? Сатан хүн дотор яаж ажилладаг вэ? Муу ёрын сүнснүүд хүн дотор хэрхэн ажилладаг вэ? Илрэлүүд нь юу вэ? Чамд ямар нэгэн зүйл тохиолдох үед энэ нь Ариун Сүнснээс ирдэг үү, чи үүнийг дуулгавартай дагах ёстой юу, эсвэл голох ёстой юу? Хүмүүсийн бодит хэрэгжүүлэлтэд хүний хүслээс ихээхэн зүйл гардаг ч хүмүүс үүнийг Ариун Сүнснээс ирдэг гэж тууштай итгэдэг. Зарим зүйл муу ёрын сүнснээс ирдэг атал хүмүүс тэдгээрийг Ариун Сүнснээс ирсэн гэж бодсоор байдаг бөгөөд заримдаа Ариун Сүнс хүмүүсийг дотроос нь залж чиглүүлдэг ч хүмүүс, ийм удирдамж Сатанаас ирдэг хэмээн айж, дуулгавартай дагаж зүрхэлдэггүй, гэтэл бодит байдал дээр тэр удирдамж нь Ариун Сүнсний гэгээрэл байдаг. Тиймээс хүн ялган салгахгүй л бол бодит туршлагаараа туулах ямар ч аргагүй юм; ялгаж салгахгүйгээр амь олж авах аргагүй. Ариун Сүнс яаж ажилладаг вэ? Муу ёрын сүнс яаж ажилладаг вэ? Хүний хүслээс юу гардаг вэ? Мөн Ариун Сүнсний удирдамж болон гэгээрлээс юу төрөн гардаг вэ? Хэрвээ чи хүний доторх Ариун Сүнсний ажлын хэв маягийг ухаарвал өдөр тутмын амьдралдаа болон бодит туршлагынхаа явцад мэдлэгээ өсгөж, ялган салгаж чадна; та нар Бурханыг мэдэж авч, Сатаныг ойлгож, ялган таньж чадна; мөн өөрсдийн дуулгавартай байдал юм уу эрэл хайгуулдаа будилж төөрөлдөхгүй бөгөөд бодол санаа нь саруул тунгалаг, Ариун Сүнсний ажлыг дуулгавартай дагадаг нэгэн байх болно.

Ариун Сүнсний ажил бол идэвх санаачилгатай удирдамж болон эерэг гэгээрлийн нэг хэлбэр юм. Энэ нь хүмүүст идэвхгүй байхыг зөвшөөрдөггүй. Энэ нь тэдэнд тайтгарал авчирч, итгэл болон шийдэмгий байдлыг өгдөг ба Бурханаар төгс болгуулахаар эрэлхийлэх боломж олгодог. Ариун Сүнс ажиллах үед хүмүүс идэвхтэйгээр орж чаддаг; тэд идэвхгүй, албадуулсан байдаггүй, харин идэвх санаачилгаараа үйлддэг. Ариун Сүнс ажиллах үед хүмүүс баяртай агаад бэлэн байдаг бөгөөд дуулгавартай байхыг хүсэж, өөрсдийгөө даруу болгохдоо баяртай байдаг. Тэд дотроо шаналалтай, сул дорой байдаг хэрнээ хамтран ажиллах шийдвэртэй байдаг; тэд дуртайяа зовж, дуулгавартай байж чаддаг, мөн хүний хүсэл, хүний бодлоор сэвтээгүй, хүний шунал болон сэдлээр лавтайяа сэвтээгүй байдаг. Ариун Сүнсний ажлыг туулах үедээ тэд дотроо тун ариун байдаг. Ариун

Сүнсний ажилтай хүмүүс Бурханыг гэх хайрыг болон ах эгч нарыг гэх хайрыг амьдран харуулдаг; тэд Бурханы баярладаг зүйлд баярлаж, Бурханы үзэн яддаг зүйлийг үзэн яддаг. Ариун Сүнсний ажлаар хөдөлгөгддөг хүмүүс хэвийн хүн чанартай байдаг бөгөөд үнэнийг байнга эрэлхийлдэг, мөн хүн чанарыг эзэмшдэг. Ариун Сүнс дотор нь ажиллах үед хүмүүсийн байр байдал улам бүр сайжирч, хүн чанар нь улам бүр хэвийн болдог бөгөөд зарим хамтын ажиллагаа нь мунхаг байж болох ч сэдэл нь зөв, оролт нь эерэг байдаг, тэд саад хийх гэж оролддоггүй, мөн тэдний дотор ямар ч хорон санаа байдаггүй. Ариун Сүнсний ажил хэвийн агаад бодитой, Ариун Сүнс хүний хэвийн амьдралын дүрмийн дагуу хүн дээр ажиллаж, хэвийн хүмүүсийн бодит эрэл хайгуулын дагуу хүмүүсийг гэгээрүүлж, залж чиглүүлдэг. Ариун Сүнс хүмүүс дээр ажиллах үедээ хэвийн хүмүүсийн хэрэгцээний дагуу залж чиглүүлж, гэгээрүүлдэг. Тэрээр хэрэгцээнийх нь дагуу тэднийг хангаж, дутагддаг зүйл болон дутагдлынх нь дагуу эергээр залж чиглүүлж, гэгээрүүлдэг. Ариун Сүнсний ажил хүмүүсийг бодит амьдрал дээр гэгээрүүлж, залж чиглүүлэхийн төлөө байдаг; тэд бодит амьдрал дээр Бурханы үгийг туулж байж л Ариун Сүнсний ажлыг харж чаддаг. Хүмүүс өдөр тутмын амьдралдаа эерэг байр байдалтай, хэвийн сүнслэг амьдралтай байвал Ариун Сүнсний ажилтай байдаг. Ийм байдалд тэд Бурханы үгийг идэж, уух үедээ итгэлтэй байдаг; залбирах үедээ урам зоригтой байдаг; ямарваа зүйл тохиолдоход идэвхгүй бус байдаг; ийм зүйл тохиолдож байхад тэд Бурханы сур хэмээн шаарддаг сургамжийг тэдгээр зүйлийн дотроос харж чаддаг. Тэд идэвхгүй, сул дорой биш байдаг бөгөөд бодит бэрхшээлтэй тулгарсан хэдий ч Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагахад бэлэн байдаг.

Ариун Сүнсний ажил ямар үр дүнд хүрдэг вэ? Чи мунхаг, ялган таних чадваргүй байж болох боловч Ариун Сүнс ажиллаж л байгаа цагт чи итгэлтэй болж, Бурханыг хангалттай хайрлаж чадахгүй байгаагаа үргэлж мэдэрнэ. Урдах бэрхшээл чинь хэчнээн их байлаа ч, чи хамтран ажиллахад бэлэн байна. Чамд ямар нэгэн юм тохиолдож, тэр нь Бурханаас ирсэн үү, эсвэл Сатанаас ирсэн үү гэдэг нь тодорхойгүй байх боловч чи хүлээж чадна, мөн идэвхгүй ч биш, хайнга ч биш байх болно. Энэ бол Ариун Сүнсний хэвийн ажил юм. Ариун Сүнс дотор чинь ажиллах үед чамд бодит бэрхшээл тулгарсаар байдаг: Заримдаа чи уйлж, заримдаа чиний даван гарч чадахгүй зүйлс байдаг боловч энэ нь бүхэлдээ Ариун Сүнсний ердийн ажлын л үе шат юм. Хэдийгээр чи тэдгээр бэрхшээлийг даван гараагүй ч, хэдийгээр тухайн үед сул дорой, гомдлоор дүүрэн байсан ч дараа нь туйлын итгэлээр Бурханыг хайрлаж бас л чадсан. Чиний идэвхгүй байдал хэвийн туршлагатай байхад чинь саад хийж чадахгүй бөгөөд бусад хүн юу ч хэлж байсан, бусад нь чам руу яаж ч дайрч довтолж байсан, Бурханыг хайрлаж мөн л чаддаг. Залбирлын үеэр чи, урьд нь Бурханд маш их өртэй байдаг байсан гэдгээ үргэлж мэдэрдэг бөгөөд тийм зүйлстэй дахин тулгарах болгондоо Бурханыг хангалуун байлгаж, махан биеэс татгалзахаар шийддэг. Энэхүү хүч чадал нь дотор чинь Ариун Сүнсний ажил байгааг харуулдаг. Энэ нь Ариун Сүнсний ажлын хэвийн байр байдал юм.

Сатанаас гардаг ажил гэж юу вэ? Сатанаас гардаг ажилд хүмүүсийн доторх үзэгдэл тодорхойгүй байдаг; хүмүүс хэвийн хүн чанаргүй, үйлдлийнх нь цаад сэдэл буруу байдаг бөгөөд хэдийгээр Бурханыг хайрлахыг хүсдэг ч дотор нь үргэлж буруутгал байдаг, эдгээр буруутгал болон бодол тэдний дотор байнга саад болж, амийнх нь өсөлтийг хязгаарлаж, Бурханы өмнө хэвийн нөхцөл байдалтай байхад нь саад хийдэг. Өөрөөр хэлбэл, Сатаны ажил хүмүүсийн дотор ормогц зүрх сэтгэл нь Бурханы өмнө тайван байж чаддаггүй. Тийм хүмүүс өөрсдийгөө яахаа мэддэггүй—хүмүүс цугларч байгааг харах үедээ зугтахыг хүсэж, бусдыг залбирч байхад нүдээ аньж чаддаггүй. Муу ёрын сүнсний ажил нь Бурхан, хүн хоёрын хоорондох хэвийн харилцааг сүйтгэж, хүмүүсийн урьдын үзэгдэл болон амийн оролтын замыг самууруулдаг; зүрх сэтгэлдээ тэд хэзээ ч Бурханд ойртож чаддаггүй ба тэднийг үймүүлж, дөнгөлөх зүйлс үргэлж тохиолддог. Тэдний зүрх сэтгэл амар тайван байж чаддаггүй бөгөөд тэдэнд Бурханыг хайрлах ямар ч хүч чадал үлдэлгүй, сүнсээрээ унасан байдаг. Энэ нь Сатаны ажлын илрэл юм. Сатаны ажлын илрэл нь: үзэл бодолдоо бат зогсож, гэрчлэлд зогсож чадахгүй байх, чамайг Бурханы өмнө буруутай, Бурханд үнэнч бус нэгэн болгох зэрэг юм. Сатан хөндлөнгөөс оролцох үед чи өөрийн доторх Бурханыг гэх хайр болон үнэнч байдлаа алдаж, Бурхантай харилцах хэвийн харилцаагаа үгүй хийдэг бөгөөд үнэнийг юм уу өөрийгөө сайжруулахаар эрэлхийлдэггүй; харин доройтож, идэвхгүй болж, өөрийгөө өөгшүүлж, нүглийн тархалтыг зоргоор нь тавьдаг ба нүглийг үзэн яддаггүй; түүнчлэн Сатаны хөндлөнгийн оролцоо нь чамайг замбараагүй болгодог; чиний дотор Бурхан сэтгэлийг чинь хөдөлгөдөг байдлыг алга болгон, Бурханы талаар гомдоллож, Бурханыг эсэргүүцэж, сэжиглэхэд чамайг хүргэдэг; тэр ч бүү хэл, чи Бурханыг орхих эрсдэлд ордог. Энэ бүхэн Сатанаас гардаг.

Өдөр тутмын амьдралд чинь ямар нэгэн зүйл тохиолдох үед Ариун Сүнсний ажлаас гарсан уу, эсвэл Сатаны ажлаас гарсан уу гэдгийг нь чи хэрхэн ялган салгах ёстой вэ? Хүмүүсийн нөхцөл байдал хэвийн байх үед сүнслэг амьдрал болон махан бие дэх амьдрал нь хэвийн байдаг, эрүүл ухаан нь хэвийн, эмх цэгцтэй байдаг. Ийм нөхцөл байдалд байх үед тэдний дотроо туулж, мэдэж авдаг зүйлийг ерөнхийд нь Ариун Сүнсээр хөдөлгөгдсөнөөс гардаг (Бурханы үгийг идэж, уух үедээ мэдлэг ухаантай байх юм уу зарим нэг энгийн мэдлэг эзэмшиж, эсвэл зарим зүйл дээр үнэнч байж, эсвэл зарим зүйл дээр Бурханыг хайрлах чадалтай байх—энэ бүхэн Ариун Сүнснээс гардаг) гэж хэлж болно. Хүн дэх Ариун Сүнсний ажил тун хэвийн байдаг; хүн үүнийг мэдрэх чадваргүй бөгөөд энэ нь хүнээр өөрөөр нь дамжиж байгаа мэт санагддаг, гэхдээ үнэндээ энэ нь Ариун Сүнсний ажил юм. Өдөр тутмын амьдралд, Ариун Сүнс хүн бүрд их, бага ажлын аль алийг хийдэг бөгөөд гагцхүү энэ ажлын хэмжээ л ялгаатай байдаг. Зарим хүн сайн хэв чанартай байдаг бөгөөд аливааг хурдан ойлгодог, тэдний доторх Ариун Сүнсний гэгээрэл ялангуяа их байдаг. Харин зарим хүн хэв чанар муутай, аливааг ойлгохдоо удаан байдаг боловч Ариун Сүнс тэднийг дотроос нь хөдөлгөдөг бөгөөд тэд ч бас Бурханд үнэнч

байж чадна—Ариун Сүнс Бурханыг эрэлхийлдэг бүх хүнд ажилладаг. Өдөр тутмын амьдралдаа хүмүүс Бурханыг эсэргүүцдэггүй, эсвэл Бурханы эсрэг тэрсэлдэггүй, Бурханы удирдлагад харшлах зүйлсийг хийдэггүй, Бурханы ажилд саад болдоггүй байх үед хүн нэг бүрд Бурханы Сүнс их, бага хэмжээгээр ажилладаг; Тэрээр тэднийг хөдөлгөж, гэгээрүүлж, тэдэнд итгэл, хүч чадал өгч, идэвх санаачилгатайгаар ороход хүргэж, мөн залхуурахгүй, махан биеийн зугаа цэнгэлд шунахгүй, үнэнийг хэрэгжүүлэхэд бэлэн байж, Бурханы үгийг хүсэн эрмэлзэхэд хүргэдэг. Энэ бүхэн нь Ариун Сүнснээс ирдэг ажил билээ.

Хүмүүсийн байр байдал хэвийн бус байх үед тэднийг Ариун Сүнс хаядаг; тэд оюун санаандаа гомдомтгой, буруу сэдэлтэй байдаг, мөн залхуурч, махан биеэ өөгшүүлж, зүрх сэтгэл нь үнэний эсрэг тэрсэлдэг. Энэ бүхэн Сатанаас гардаг. Хүмүүсийн нөхцөл байдал хэвийн бус байх үед, мөн тэдний дотор харанхуй байж, хэвийн эрүүл ухаанаа алдаж, Ариун Сүнсэнд хаягдаж, өөрсдийнхөө дотор Бурханыг мэдэрч чадахгүй байх үед дотор нь Сатан ажиллаж байгаа юм. Хэрвээ хүмүүс дотроо үргэлж хүч чадалтай байж, Бурханыг үргэлж хайрладаг бол ерөнхийдөө аливаа зүйлс тэдэнд тохиолдох үед тэдгээр нь Ариун Сүнснээс ирдэг ба тэд хэнтэй ч уулзсан бай, тэр уулзалт нь Бурханы зохицуулалтын үр дүн байдаг. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдал чинь хэвийн байх үед, мөн чамайг Ариун Сүнсний агуу ажил дотор байх үед Сатан чамайг ганхуулах боломжгүй. Энэхүү суурин дээр юм бүхэн Ариун Сүнснээс ирдэг гэж хэлж болох бөгөөд хэдий чамд буруу бодол байж болох ч тэдгээрээс татгалзаж, дагахгүй байж чадна. Энэ бүхэн Ариун Сүнсний ажлаас гардаг. Сатан ямар нөхцөл байдалд хөндлөнгөөс оролцдог вэ? Нөхцөл байдал чинь хэвийн бус байх үед, Бурханаар хөдөлгөгдөөгүй, Бурханы ажилгүй, дотроо уйтгартай, хоосон байх үед, Бурханд залбирсан ч юу ч ухаарахгүй, Бурханы үгийг идэж, уухдаа ч гэгээрүүлэгдэж, гэрэлтүүлэгдэхгүй байх үед та нарын дотор Сатан ажиллахад амархан байдаг. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнсэнд хаягдаж, Бурханыг мэдэрч чадахгүй байх үед чинь Сатаны уруу таталтаас гардаг олон зүйл та нарт тохиолддог. Ариун Сүнсийг ажиллаж байхад Сатан ч бас нэгэн зэрэг ажилладаг байгаа. Ариун Сүнс хүний сэтгэл доторхыг хөдөлгөхийн сацуу Сатан хүнд саад болдог. Гэхдээ Ариун Сүнсний ажил тэргүүлэх байр суурийг эзэлдэг бөгөөд нөхцөл байдал нь хэвийн хүмүүс ялалт байгуулж чаддаг, энэ нь Ариун Сүнсний ажил Сатаны ажлыг ялан дийлж байгаа хэрэг юм. Харин Ариун Сүнсийг ажиллах үед хүмүүсийн дотор завхарсан зан чанар байсаар байдаг; гэхдээ Ариун Сүнсний ажлын үеэр хүмүүсийн хувьд өөрсдийнхөө тэрслүү байдал, сэдэл, хольцыг олж мэдэж, танихад амархан байдаг. Тэр үед л хүмүүс харуусаж, гэмших хүсэлтэй болдог. Ийм болохоор тэдний тэрслүү, завхарсан зан чанар Бурханы ажил дотор аажмаар хаягддаг. Ариун Сүнсний ажил нэн хэвийн байдаг; Түүнийг хүмүүс дээр ажиллахад хүмүүст мөн л бэрхшээл тохиолдоно, тэд мөн л уйлж, зовж, сул дорой байдаг бөгөөд тэдний хувьд тодорхойгүй зүйл их байсаар байдаг, гэхдээ ийм байдалд тэд уруудан доройтохоо больж, Бурханыг хайрлаж чаддаг, мөн хэдий

тэд уйлж, дотроо шаналж байсан ч Бурханыг магтах чадвартай хэвээр байдаг; Ариун Сүнсний ажил тун хэвийн бөгөөд өчүүхэн төдий ч ер бусын биш. Ариун Сүнсийг ажиллаж эхэлмэгц хүмүүсийн байр байдалд өөрчлөлт гарч, тэдний хувьд үндсэн зүйлс арилдаг гэж ихэнх хүмүүс итгэдэг. Тийм итгэл нь эндүү ташаа юм. Ариун Сүнс хүний дотор ажиллах үед хүний идэвхгүй зүйлс байсаар байдаг бөгөөд биеийн хэмжээ нь өөрчлөгдөлгүй хэвээр үлддэг ч тэрээр Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг олж авдаг тул түүний байр байдал илүү идэвх санаачилгатай, доторх нөхцөл байдал нь хэвийн байдаг ба тэрээр хурдан өөрчлөгддөг. Бодит туршлагаараа хүмүүс үндсэндээ Ариун Сүнсний юм уу Сатаны ажлыг туулдаг бөгөөд хэрвээ тэд эдгээр байр байдлыг ухаарч, ялган салгаж чадахгүй бол бодит туршлагад орох огт боломжгүй, зан чанарын өөрчлөлтийн тухайд бол ярихын ч хэрэггүй. Тиймээс Бурханы ажлыг туулахын гол түлхүүр нь ийм зүйлсийг нэвт шувт харж чаддаг байх явдал юм; ийм маягаар, тэдний хувьд үүнийг туулахад илүү амархан байх болно.

Ариун Сүнсний ажил нь хүмүүст эерэг ахиц гаргах боломж олгодог байхад Сатаны ажил нь тэднийг сөрөг болж, ухарч няцаж, Бурханы эсрэг тэрсэлж, Бурханыг эсэргүүцэж, Бурханд итгэл алдаж, үүргээ биелүүлэхдээ сул дорой болоход хүргэдэг. Ариун Сүнсний гэгээрлээс үүдэн гардаг бүхэн нь нэлээд ердийн байдаг; энэ нь чамайг хүчилдэггүй. Хэрвээ чи дуулгавартай дагавал амар тайван байна; дуулгаваргүй бол дараа нь зэмлүүлнэ. Ариун Сүнсний гэгээрэлтэйгээр чиний хийдэг юу ч хязгаарлагдаж, саатуулагдахгүй, чи чөлөөтэй байх ба чиний үйлдлүүдэд хэрэгжүүлэх зам байх болно, чи ямар нэгэн хязгаарлалтад автахгүй, харин Бурханы хүсэлд үндэслэн үйлдэж чадна. Сатаны ажил олон зүйл дээр чамд саад учруулдаг; энэ нь чамайг залбирах хүсэлгүй, Бурханы үгийг идэж, уухад хэтэрхий залхуу, чуулганы амьдралаар амьдрах дургүй болгодог бөгөөд чамайг сүнслэг амьдралаас хөндийрүүлдэг. Ариун Сүнсний ажил өдөр тутмын амьдралд чинь саад болдоггүй бөгөөд хэвийн сүнслэг амьдралд чинь саад болдоггүй. Тохиолдож байх яг тэр хоромд нь та нар олон зүйлийг ялган салгаж чаддаггүй ч хэдэн өдрийн дараа зүрх сэтгэл чинь гэрэлтэж, оюун санаа чинь цэлмэдэг. Чи сүнсний зүйлсийн талаар бага зэрэг мэдэрдэг болж, тухайн бодол Бурханаас ирсэн үү, Сатанаас ирсэн үү гэдгийг аажмаар ялган таньж чаддаг. Зарим зүйл чамайг Бурханыг илт эсэргүүцэж, Бурханы эсрэг тэрслэхэд хүргэдэг, эсвэл Бурханы үгийг хэрэгжүүлэхийг чинь болиулдаг; эдгээр зүйл бүгд Сатанаас гардаг. Зарим зүйл илэрхий биш байдаг бөгөөд тухайн үедээ та нар ялган таньж чаддаггүй; дараа нь тэдгээрийн илрэлийг хараад, ялган таньж чаддаг. Хэрвээ чи аль зүйл Сатанаас гардаг, алийг нь Ариун Сүнс чиглүүлдгийг тодорхой ялган салгаж чаддаг бол өөрсдийнхөө туршлагад амархан төөрөлдөхгүй. Заримдаа нөхцөл байдал чинь сайнгүй байх үед чамайг идэвхгүй байдлаас гаргах тодорхой бодол чамд төрдөг. Нөхцөл байдал чинь таагүй байх үед ч зарим бодол чинь Ариун Сүнснээс бас гарч болно гэдгийг энэ нь харуулдаг. Чамайг идэвхгүй байх үед бүх бодлыг чинь Сатан

илгээдэг юм биш; хэрвээ тийм байсан бол чи хэзээ идэвхтэй байдал руу өөрчлөгдөж чадах юм бэ? Хэсэг хугацаанд идэвхгүй байснаа Ариун Сүнс чамд төгс болгуулах боломж өгдөг; Тэрээр чамайг хөдөлгөж, идэвхгүй байдлаас чинь гаргаж, чи хэвийн байдалд ордог.

Ариун Сүнсний ажил юу болохыг, Сатаны ажил юу болохыг мэдсэнээр туршлагынхаа явцад чи эдгээрийг өөрийнхөө байр байдалтай болон хувийн туршлагатай харьцуулж болох бөгөөд ийм маягаар, зарчимтай холбоотой илүү олон үнэн туршлагад чинь байх болно. Зарчмын тухай эдгээр үнэнийг ойлгоод чи өөрийнхөө бодит байдлыг хянах чадвартай болж, хүмүүс, үйл явдлыг ялган салгаж чаддаг болох бөгөөд Ариун Сүнсний ажлыг олж авахын тулд маш их хичээл чармайлт зарцуулах хэрэггүй болно. Мэдээж, энэ нь чиний сэдэл зөв байгаагаас, эрж хайж, хэрэгжүүлэхийг хүсэж байгаагаас хамаардаг. Иймэрхүү хэл—зарчимтай холбоотой хэл нь чиний туршлагад байх ёстой. Үүнгүйгээр чиний туршлага Сатаны хөндлөнгийн оролцоо болон мунхаг мэдлэгээр дүүрэн байх болно. Хэрвээ чи Ариун Сүнс хэрхэн ажилладгийг ойлгодоггүй бол Бурханд хэрхэн залбирахаа эсвэл хэрхэн орох учиртайгаа ойлгодоггүй бөгөөд Сатан хүмүүсийг залилж, үймүүлэхийн тулд хэрхэн үйлддэгийг ойлгохгүй бол хэрхэн Сатаныг голж, гэрчлэлдээ бат зогсохоо мэдэхгүй. Ариун Сүнс яаж ажилладаг, Сатан яаж үйлддэг нь хүмүүсийн ойлгох ёстой зүйл, Бурханд итгэхдээ хүмүүсийн туулах ёстой зүйлс билээ.

ҮНЭНИЙГ ХЭРЭГЖҮҮЛДЭГГҮЙ ХҮМҮҮСТ ӨГӨХ АНХААРУУЛГА

Ах эгч нарын дунд сөрөг байдлаа үргэлжид гаргагчид нь Сатаны боолууд бөгөөд тэд чуулганыг үймүүлдэг. Тийм хүмүүс нэг л өдөр хөөгдөж, таягдан хаягдах ёстой. Хүмүүс Бурханд итгэхдээ Бурханыг хүндлэх сэтгэл өвөрлөдөггүй, Бурханыг дуулгавартай дагах зүрх сэтгэлгүй бол Түүний төлөө ямар ч ажил хийж чадахгүйгээр үл барам, харин ч эсрэгээрээ Түүний ажлыг үймүүлж, Түүнийг эсэргүүцдэг хүмүүс болно. Бурханд итгэдэг боловч Түүнд дуулгавартай байж, Түүнийг хүндлэлгүй, харин ч Түүнийг эсэргүүцэх нь итгэгчийн хувьд асар их гутамшиг юм. Хэрвээ итгэгчид, үл итгэгчдийн адилаар үг хэл, үйл хөдлөл нь ямагт хайхрамжгүй, цадиггүй байдаг бол тийм хүмүүс үл итгэгчдээс ч илүү ёрын муу юм; тэд бол жинхэнэ чөтгөр мөн. Чуулган дотор хорт, хорон муу яриагаа дэгдээдэг, ах эгч нарын дунд цуу яриа тарааж, зөрчил үүсгэж, бүлэглэл бий болгодог хүмүүс чуулганаас хөөгдсөн байх ёстой. Гэвч одоо Бурханы ажлын өөр эрин үе тул энэ хүмүүсийг хязгаарласан, учир нь тэд гарцаагүй таягдан хаягдана. Сатаны завхруулсан бүх хүн завхарсан зан чанартай байдаг. Зарим хүн завхарсан зан чанараас цаашгүй байхад бусад нь тийм биш: Тэд завхарсан сатанлаг зан чанартайгаар зогсохгүй, уг чанар нь ч бас туйлын хорон муу байдаг. Тэдний үг,

үйлдэл завхарсан сатанлаг зан чанарыг нь илчилдгээр үл барам, энэ хүмүүс бол жинхэнэ диавол Сатан юм. Тэдний зан авир Бурханы ажилд саад болж, үймүүлэн, ах эгч нарын амийн оролтыг үймүүлж, чуулганы хэвийн амьдралд саад хийж байдаг. Хонины арьс нөмөрсөн энэ чононуудыг эрт орой хэзээ нэгэн цагт цэвэрлэх ёстой; Сатаны энэ боолуудад өршөөлгүй хандаж, голж харьцах ёстой. Ингэх нь л Бурханы талд зогсож буй хэрэг; ингэж чаддаггүй хүмүүс Сатантай хамт намаг балчигт хөлбөрч байна. Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан үргэлж байдаг агаад Бурханыг хүндэлж, хайрладаг зүрх сэтгэлийг дотроо үргэлж тээдэг. Бурханд итгэдэг хүмүүс аливааг хянамгай, болгоомжтой хийх ёстой, бүх зүйлийг Бурханы шаардлагад нийцүүлж, Түүний зүрх сэтгэлийг хангалуун байлгахын тулд хийх хэрэгтэй. Тэд дур зоргоороо байж, хүссэн болгоноо хийх ёсгүй; ариун хүний ёс журамд энэ тохирохгүй. Хүмүүс хяналтаа алдаж, хаа сайгүй Бурханы туг далбааг намируулангаа энд тэндгүй сайрхаж, хууран мэхэлж болохгүй; энэ нь хамгийн тэрслүү үйлдэл юм. Гэр бүлд дүрэм журам, улс үндэстэнд хууль цааз гэж бий; тэгвэл Бурханы гэрт үүнээс ч илүү байх бус уу? Бүр ч хатуу чанд стандарттай байх бус уу? Бүр ч их захиргааны зарлигтай байх бус уу? Хүмүүс юу хүссэнээ хийж болох боловч Бурханы захиргааны зарлигийг хүссэнээрээ өөрчилж болохгүй. Бурхан бол хүмүүсийн халдахыг тэвчдэггүй Бурхан; Тэр бол хүмүүсийг үхүүлдэг Бурхан. Хүмүүс үүнийг үнэхээр аль хэдийн мэдэх бус уу?

Чуулганыг үймүүлж, Бурханы ажилд саад болдог хүмүүс чуулган болгонд бий. Тэд бүгд Бурханы гэрт шургалан орсон, зүсээ хувиргасан Сатан юм. Ийм хүмүүс дүр эсгэхдээ нэн сайн байдаг; тэд Миний өмнө хүндэтгэлтэйгээр ирж, бөхөлзөн, хамуутай нохой шиг амьдарч, хувийн зорилгодоо хүрэхийн тулд “бүхнээ” зориулдаг боловч ах эгч нартай нүүр тулах үедээ муу муухай талаа харуулдаг. Тэд үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүсийг хараад тэдэн рүү дайрч давшлан, хажуу тийш нь түлхэж хаядаг; өөрсдөөс нь илүү аймшигтай хүмүүсийг харахаараа долигонож, зусарддаг, чуулган дотор дураараа дургидаг. Иймэрхүү “орон нутгийн дээрэнгүй этгээд”, иймэрхүү “уяаны нохой” ихэнх чуулган дотор байдаг гэж хэлж болно. Тэд хамтдаа диавол шиг үйлдэж, нэг нэгэн рүүгээ ирмэн, сэмхэн дохио өгдгийн дээр хэн нь ч үнэнийг хэрэгжүүлдэггүй. Хамгийн хорт нэгэн нь “ахлах чөтгөр” болж, хамгийн нэр хүндтэй нь бусдыгаа удирдаж, туг далбаагаа өндөрт өргөдөг. Энэ хүмүүс чуулган даяар галзуурсан мэт авирлаж, сөрөг байдлаа тарааж, үхэл ханхлуулж, хүссэнээ хийж, юу дуртайгаа хэлдэг; хэн ч тэднийг зогсоож зүрхэлдэггүй, тэд сатанлаг зан чанараар дүүрэн байдаг. Тэднийг үймээн тарьж эхлэнгүүт үхлийн уур амьсгал чуулганд орж ирдэг. Чуулган дахь үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс жигшигдэн гологдож, бүхнээ зориулах боломжгүй болдог байхад чуулганыг үймүүлж, үхэл тараадаг хүмүүс чуулган дотор галзуурсан мэт авирлаж байдаг. Түүгээр ч үл барам, ихэнх хүн тэднийг дагадаг. Ийм чуулганыг гагцхүү Сатан захирч байдаг; диавол хаан нь юм. Хэрвээ чуулганы гишүүд өндийн босож, эдгээр ахлах чөтгөрийг эсэргүүцэхгүй бол өөрсдөө ч гэсэн эрт орой хэзээ нэгэн цагт сүйрэх болно.

Одоогоос эхлэн, ийм чуулгануудын эсрэг арга хэмжээ авах ёстой. Үнэнийг бага ч гэсэн хэрэгжүүлэх чадвартай хүмүүс үнэнийг эрж хайдаггүй бол тэр чуулганыг бүрмөсөн хориглоно. Үнэнийг хэрэгжүүлэх хүсэлтэй нэг ч хүн үгүй, Бурханы төлөө гэрчлэлд зогсож чадах хэн ч байхгүй бол тэр чуулганыг нэгмөсөн тусгаарлаж, бусад чуулганаас холбоог нь таслах ёстой. Үүнийг “үхлийг булшлах” гэж нэрлэдэг; Сатаныг жигшин голох гэдэг нь энэ юм. Хэрэв чуулганд нутгийн хэдэн дээрэнгүй этгээд байдаг агаад ямар ч ялган таних чадваргүй “жижиг ялаанууд” тэднийг дагадаг бол, хэрэв чуулганы гишүүд үнэнийг харсныхаа дараа ч гэсэн эдгээр дээрэнгүй этгээдийн хүлээс, явуулгаас салж чадахгүй хэвээр байгаа бол тэр тэнэгүүд эцэстээ бүгд таягдан хаягдана. Энэхүү жижиг ялаанууд ямар нэгэн аймшигтай зүйл хийгээгүй байж болох ч бүр илүү ов мэхтэй, бүр илүү зальхай, булзамхай байдаг, ийм хүн бүрийг таягдан хаяна. Ганцыг ч үлдээхгүй! Сатанд харьяалагддаг хүмүүс Сатан руу буцах бол Бурханд харьяалагддаг хүмүүс үнэнийг эрж хайж явах нь гарцаагүй; энэ нь тэдний уг чанараар шийдэгддэг. Сатаныг дагадаг бүх хүн мөхөөсэй! Ийм хүмүүст өрөвч сэтгэл огт гаргахгүй. Үнэнийг хайдаг хүмүүс хангалт хүртэж, шавайгаа ханатал Бурханы үгэнд баясах болтугай. Бурхан бол зөвт; Тэр хэнийг ч алагчилдаггүй. Хэрвээ чи диавол бол үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг; хэрвээ чи үнэнийг хайдаг нэгэн бол Сатанд олзлогдохгүй нь лавтай. Энэ ямар ч эргэлзээгүй.

Ахиж дэвшихээр чармайдаггүй хүмүүс бусдыг өөрсөд шигээ идэвхгүй, хойрго байгаасай гэж үргэлж хүсдэг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс хэрэгжүүлдэг хүмүүст атаархаж, мунгинуу, ялган таних чадвараар дутмаг хүмүүсийг хуурч мэхлэхийг үргэлж оролддог. Энэ хүмүүсийн гаргадаг зүйлс нь чамайг доройтуулж, хөл алдуулж, хэвийн бус байдалтай болгож, харанхуйгаар дүүргэж чадна; тэд чамайг Бурханаас холдуулж, махан биеэ энхрийлэн, өөрийгөө өөгшүүлэхэд хүргэдэг. Үнэнийг хайрладаггүй, Бурхантай үргэлж хааш яаш харьцдаг хүмүүс өөрийгөө мэддэггүй; тийм хүмүүсийн зан чанар нь бусдыг нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэхэд уруу татдаг. Тэд үнэнийг хэрэгжүүлдэггүй, бусдаар ч хэрэгжүүлүүлдэггүй. Тэд нүглийг нандигнадгийн дээр өөрсдийгөө жигшинэ гэж байдаггүй. Тэд өөрсдийгөө мэддэггүй, бусдад өөрсдийгөө танин мэдэхэд нь саад болдог; бас бусдад үнэнийг хүсэн тэмүүлэхэд нь саад болдог. Тэдэнд мэхлэгдсэн хүмүүс гэрлийг харж чадалгүй харанхуйд унаж, өөрсдийгөө мэдэхгүй, үнэний талаар тодорхой мэдэхгүй, Бурханаас улам бүр холддог. Тэд үнэнийг хэрэгжүүлдэггүй, бусад хүнд үнэнийг хэрэгжүүлэхэд саад болж, тэр бүх мунхаг хүнийг өөрсдийн өмнө авчирдаг. Бурханд итгэдэг гэж хэлэхийн оронд тэд өвөг дээдэстээ итгэдэг эсвэл итгэдэг зүйл нь тэдний зүрх сэтгэл дэх шүтээнүүд гэдгээ хэлбэл дээр сэн. Бурханыг дагадаг гэцгээдэг хүмүүс нүдээ нээгээд, яг хэнд итгэдгээ нэг сайн харсан нь дээр шүү: Итгэдэг зүйл чинь үнэхээр Бурхан уу, эсвэл Сатан уу? Хэрвээ итгэдэг зүйл чинь Бурхан биш, харин өөрийн чинь шүтээнүүд гэдгийг мэдэж байгаа бол өөрийгөө итгэгч гэж хэлэхгүй байсан нь дээр. Хэрвээ чи хэнд итгэдгээ үнэхээр мэдэхгүй байгаа бол мөн л өөрийгөө итгэгч

гэж хэлэхгүй байсан нь дээр. Тэгж хэлэх нь доромжлол болно! Хэн ч чамайг Бурханд итгэ гэж хүчлээгүй. Надад итгэдэг гэж та нар бүү хэл; ийм яриаг Би хангалттай их сонссон бөгөөд дахин сонсохыг хүсэхгүй байна, учир нь итгэдэг зүйл чинь та нарын зүрх сэтгэл дэх шүтээнүүд, мөн та нарын дундах нутгийн дээрэнгүй этгээдүүд юм. Үнэнийг сонсох үедээ толгойгоо сэгсэрч, үхлийн талаарх яриа сонсоод учиргүй инээдэг хүмүүс бүгд Сатаны үр сад; тэд бүгд таягдан хаягдах болно. Чуулганд ялган таних чадваргүй олон хүн бий. Ямар нэгэн төөрөлдүүлсэн зүйл болоход тэд санамсаргүй Сатаны талд зогсдог; Сатаны боол гэж дуудсанд бүр гомддог. Өөрт нь ялган таних чадвар байхгүй гэж хүмүүс хэлж магад боловч тэд үргэлж үнэнгүй талд зогсдог, шийдвэрлэх чухал цаг үед үнэний талд хэзээ ч зогсож байгаагүй, хэзээ ч үнэний төлөө өндийн босож, мэтгэлцэж байгаагүй. Тэд үнэхээр ялган таних чадваргүй гэж үү? Тэд яагаад санаандгүйгээр Сатаны талд ордог юм бэ? Яагаад тэд үнэнийг дэмжиж нэг ч болтугай шударга, үндэслэлтэй үг хэлдэггүй юм бэ? Энэ нөхцөл байдал үнэхээр тэдний агшин зуурын төөрөгдлөөс үүссэн гэж үү? Хүмүүсийн ялган таних чадвар бага байх тусам, үнэний талд зогсож чадах нь бага байдаг. Энэ юуг харуулдаг вэ? Ялган таних чадваргүй хүмүүс ёрын мууд хайртай гэдгийг харуулдаг бус уу? Тэд бол Сатаны үнэнч үр сад гэдгийг харуулдаг бус уу? Яагаад тэд үргэлж Сатаны талд зогсож, түүний хэлээр ярьж чаддаг юм бэ? Үг үйлдэл бүр нь, нүүр царайны илэрхийлэл нь тэд үнэнийг огт хайрладаггүй; харин ч үнэнийг жигшдэг хүмүүс гэдгийг нь хангалттай нотолдог. Тэд Сатаны талд зогсож чадна гэдэг нь бүх амьдралаа өөрийнх нь төлөө тэмцэж өнгөрүүлдэг эдгээр өчүүхэн диаволд Сатан үнэхээр хайртай гэдгийг нотлоход хангалттай юм. Энэ бүх баримт дэндүү тодорхой бус уу? Хэрвээ чи үнэхээр үнэнийг хайрладаг хүн мөн бол яагаад үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүсийг хүндэлдэггүй юм бэ, үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс дөнгөж харангуут нь яагаад тэднийг тэр даруй дагадаг юм бэ? Энэ ямар гэгчийн асуудал вэ? Чамд ялган таних чадвар байгаа эсэх нь Надад хамаагүй. Хэчнээн их төлөөс төлсөн чинь Надад хамаагүй. Хэчнээн их хүчтэй чинь Надад хамаагүй, нутгийн дээрэнгүй этгээд байна уу эсвэл туг баригч удирдагч байна уу Надад хамаагүй. Хүч чинь асар их байвал Сатаны хүч чадал л тусалсных. Нэр хүнд чинь өндөр байвал эргэн тойронд чинь үнэнийг хэрэгжүүлдэггүй хүн дэндүү олон байгаагийнх. Хэрвээ чи хөөгдөөгүй байгаа бол одоо хөөн зайлуулах ажлын цаг үе болоогүй байгаагийнх; харин ч таягдах ажлын цаг үе юм. Чамайг одоо хөөх гэж яарахгүй. Таягдуулсны чинь дараа чамайг шийтгэх тэр өдөр ирэхийг л Би хүлээж байгаа. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хэн бүхэн таягдан хаягдана!

Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг хүмүүс бол Бурханы үгийг хэрэгжүүлэх хүсэлтэй, үнэнийг хэрэгжүүлэх хүсэлтэй хүмүүс юм. Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсож үнэхээр чаддаг хүмүүс нь бас Түүний үгийг хэрэгжүүлэх хүсэлтэй, үнэний талд жинхэнээсээ зогсож чадах хүмүүс юм. Заль мэх хэрэглэж, шударга бусыг үйлддэг хүмүүс бүгд үнэнгүй бөгөөд бүгдээрээ Бурханд шившиг авчирдаг. Чуулганд

хэрүүл маргаан үүсгэдэг хүмүүс нь Сатаны боолууд, Сатаны биелэл юм. Ийм хүмүүс маш хорлонтой. Ялган таних чадваргүй, үнэний талд зогсох чадваргүй хүмүүс бүгд хорон муу санаа өвөрлөж, үнэнийг гутаадаг. Түүгээр ч барахгүй тэд бол Сатаны ердийн төлөөлөгч юм. Тэднийг аврахын аргагүй бөгөөд мэдээжийн хэрэг таягдан хаях болно. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүсийг Бурханы гэр бүл үлдэхийг зөвшөөрдөггүй, чуулганыг санаатайгаар нураадаг хүмүүст ч үлдэхийг зөвшөөрдөггүй. Гэвч одоо бол хөөн зайлуулах ажил хийх цаг биш; тийм хүмүүс эцэстээ зүгээр л илчлэгдэж, таягдан хаягдана. Энэ хүмүүс дээр дахин ямар ч хэрэггүй ажил зарлагадахгүй; Сатанд харьяалагддаг хүмүүс үнэний талд зогсож чаддаггүй байхад үнэнийг эрж хайдаг хүмүүс чаддаг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс үнэний замыг сонсож, үнэнийг гэрчлэх эрхгүй. Үнэн ердөө л тэдний чихэнд зориулагдаагүй; харин ч хэрэгжүүлдэг хүмүүст хандсан байдаг. Хүн бүрийн төгсгөл илчлэгдэхээс өмнө чуулганыг үймүүлж, Бурханы ажилд саад хийдэг хүмүүсийг одоохондоо эхлээд хойш тавьж, дараа нь зохицуулна. Ажил дуусмагц энэ хүмүүсийг нэг нэгээр нь илчилж, дараа нь таягдан хаяна. Одоохондоо, үнэнээр хангаж байх үед тэднийг үл ойшооно. Үнэн бүхэлдээ хүнд илчлэгдэх үед тэр хүмүүсийг таягдан хаях ёстой; тэр цаг үе нь бүх хүнийг төрлийнх нь дагуу ангилах цаг үе байна. Ялган таних чадваргүй хүмүүс ялихгүй заль мэхнийхээ улмаас ёрын муу хүмүүсийн гарт сүйрч, уруу татагдан, хэзээ ч эргэж ирэхгүй. Тэд үнэнийг хайрладаггүй, үнэний талд зогсох чадваргүй, муу хүмүүсийг дагаж, тэдний талд зогсдог, муу хүмүүстэй сүлбэлдэж, Бурханыг эсэргүүцдэг учраас тэдэнд ингэж хандвал зохино. Муу хүмүүс ёрын мууг ялгаруулдаг гэдгийг тэд маш сайн мэддэг атлаа зүрх сэтгэлээ чангалан, үнэнээс нүүр буруулж тэднийг дагадаг. Үнэнийг хэрэгжүүлдэггүй мөртөө хөнөөлтэй, ой гутам зүйлсийг хийгч энэ хүмүүс бүгд мууг үйлдэж байгаа бус уу? Тэдний дунд өөрсдийгөө хаан гэж нэрийддэг, мөн тэднийг дагадаг бусад хүн байгаа хэдий ч Бурханыг эсэргүүцдэг уг чанар нь бүгд адил бус уу? Бурхан өөрсдийг нь авардаггүй гэж хэлэх ямар шалтаг тэдэнд байх юм бэ? Бурханыг зөвт бус гэж хэлэх ямар шалтаг тэдэнд байх юм вэ? Өөрсдийнх нь ёрын муу байдал тэднийг сүйрүүлж байгаа бус уу? Өөрсдийнх нь тэрслүү байдал там руу чирч байгаа бус уу? Үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс эцэст нь үнэний улмаас аврагдаж, төгс болгуулна. Үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс эцэстээ үнэний улмаас өөртөө сүйрэл авчрах болно. Үнэнийг хэрэгжүүлдэг болон хэрэгжүүлдэггүй хүмүүсийг хүлээж буй төгсгөл ийм билээ. Бүр илүү их нүгэл үйлдэхээс зайлсхийж нэн даруй чуулганыг орхи гэж Би үнэнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөгүй хүмүүст зөвлөе. Цаг нь ирэхээр гэмшихэд хэтэрхий оройтсон байх болно. Ялангуяа бүлэглэл бий болгож, хагарал үүсгэдэг хүмүүс, чуулган доторх нутгийн дээрэнгүй этгээдүүд бүр эрт явах ёстой. Ёрын муу чонын уг чанартай ийм хүмүүс өөрчлөгдөж чадахгүй. Тэд Бурханы шийтгэлээс зайлсхийхийн тулд аль болох эртхэн чуулганаас явж ах эгч нарын хэвийн амьдралыг дахин хэзээ ч үймүүлэхгүй байсан нь дээр. Тэднийг дагаж явсан хүмүүс та нар энэ боломжийг ашиглаж, өөрсдөө

эргэцүүлбэл сайн. Та нар ёрын муу хүмүүстэй хамт чуулганаас явах уу эсвэл үлдэж, дуулгавартай дагах уу? Энэ асуудлыг няхуур авч үзэх ёстой. Би та нарт сонголт хийх дахин нэг боломж өгье; хариултыг чинь Би хүлээж байна.

ЧИ БУРХАНД ӨГСӨН ҮНЭНЧ БАЙДЛАА ХАДГАЛАХ ЁСТОЙ

Ариун Сүнс өнөө үед чуулган дотор хэрхэн ажиллаж байна вэ? Чи энэ асуудлыг баттай ойлгож ухаарсан уу? Ах эгч нарын чинь хамгийн том бэрхшээл юу вэ? Тэдэнд юу хамгийн их дутагддаг вэ? Одоогоор зарим хүн шалгалт туулахдаа сөрөг байдаг, зарим нь бүр гомдоллодог. Бурхан үгээ хэлж дууссан учраас зарим хүн урагшлахаа больдог. Хүмүүс Бурханд итгэх итгэлийн зөв замд ороогүй. Тэд бие даан амьдарч чаддаггүй бөгөөд сүнслэг амьдралаа хадгалж чаддаггүй. Зарим хүн Бурханыг ярих үед ойрхон дагаж, эрч хүчтэйгээр эрэлхийлж, хэрэгжүүлэхэд бэлэн байдаг боловч Бурхан үг хэлэхгүй үед тэд урагшлахаа больдог. Хүмүүс Бурханы хүслийг зүрх сэтгэлдээ ойлгоогүй хэвээр, Бурханыг аяндаа хайрлах хайр тэдэнд байдаггүй; өмнө нь тэд албан хүчээр Бурханыг дагадаг байсан. Бурханы ажлаас залхдаг зарим хүн одоо бий. Ийм хүмүүс аюулд байгаа биш гэж үү? Маш олон хүн зүгээр л аргацаах байдалтай байдаг. Хэдийгээр тэд Бурханы үгийг идэж ууж, Түүнд залбирдаг ч үүнийгээ хайнга хийдэг бөгөөд нэгэн цагт байсан урам зориг нь тэдэнд байхаа больсон. Ихэнх хүн Бурханы цэвэршүүлж, төгс болгох ажлыг сонирхдоггүй, үнэндээ тэдэнд ямар ч дотоод хөдөлгөгч хүч байхгүй мэт ямагт байдаг. Тэд гэм бурууд дийлдсэн ч Бурханд өртэй гэдгээ мэдэрдэггүй, бас харамсахаа ч мэддэггүй. Тэд үнэнийг эрэлхийлдэггүй, бас чуулганыг орхидоггүй, харин түр зуурын зугаа цэнгэл л эрж хайдаг. Энэ хүмүүс бол мунхаг, хамгийн усан тэнэг! Цаг нь ирэхэд тэд бүгд хаягдаж, нэг нь ч аврагдахгүй! Хэрвээ нэг удаа аврагдсан бол үргэлж аврагдана гэж чи боддог уу? Ийм итгэл үнэмшил нь цэвэр залилан! Амийн оролтыг эрэлхийлдэггүй бүх хүн гэсгээгдэнэ. Ихэнх хүн амийн оролт, үзэгдлүүд, үнэний хэрэгжүүлэлтийг огтхон ч сонирхдоггүй. Тэд оролтыг эрэлхийлдэггүй, илүү гүнзгий оролтыг гарцаагүй эрэлхийлдэггүй. Тэд өөрсдийгөө сүйрүүлж байгаа бус уу? Яг одоо нөхцөл байдал нь байнга сайжирч байгаа хэсэг хүмүүс бий. Ариун Сүнс ажиллах тусам тэд илүү их итгэлтэй болдог; тэд туршлагажих тусмаа Бурханы ажлын гүн гүнзгий нууцыг төдий чинээ их туулдаг. Илүү гүнзгий орох тусмаа тэд илүү их ойлгодог. Тэд Бурханы хайр маш агуу гэдгийг мэдэрч, дотроо тайван, гэгээрсэн санагддаг. Тэд Бурханы ажлын талаар ойлголттой байдаг. Энэ бол Ариун Сүнс дотор нь ажиллаж байгаа хүмүүс юм. Зарим хүн, “Бурханы шинэ үг байхгүй байсан ч би үнэнийг илүү гүнзгий эрж хайсаар байх ёстой, өөрийн бодит туршлагын бүх зүйлд нухацтай хандаж, Бурханы үгийн бодит байдал руу орох ёстой” гэж хэлдэг. Ийм хүнд Ариун Сүнсний ажил байдаг. Хэдийгээр Бурхан хүн нэг бүрд

царай төрхөө харуулдаггүй, тэднээс нуугдаж, ганц ч үг айлддаггүй, хүмүүс заримдаа дотроо бага зэрэг цэвэршүүлэлт туулдаг ч Бурхан хүмүүсийг бүрэн орхиогүй. Хэрвээ хүн өөрийн хэрэгжүүлэх ёстой үнэнийг хадгалж чадахгүй бол түүнд Ариун Сүнсний ажил байхгүй байх болно. Цэвэршүүлэлтийн хугацаанд, Бурхан Өөрийгөө харуулахгүй байх хугацаанд хэрвээ чи өөртөө итгэлгүй байж, харин ч зайлан холддог бол, Бурханы үгийг туулахад анхаарлаа хандуулдаггүй бол энэ нь Бурханы ажлаас зугтааж байгаа хэрэг юм. Хожим нь чи хаягдах хүмүүсийн нэг болох болно. Бурханы үг рүү орохоор эрж хайдаггүй хүмүүс Түүний төлөө гэрчлэлд зогсож яавч чадахгүй. Бурханы төлөө гэрчлэл хийж, Түүний хүслийг хангаж чаддаг хүмүүс бүгд Бурханы үгийг эрэлхийлэх урам зоригоосоо бүрэн хамааралтай байдаг. Хүмүүст Бурханы гүйцэтгэдэг ажил нь үндсэндээ үнэнийг олж авах боломжийг тэдэнд олгохын тулд байдаг; чамаар амийг эрэлхийлүүлэх нь чамайг төгс болгохын төлөө байдаг бөгөөд энэ бүгд нь чамайг Бурханд ашиглагдахад тохирохуйц болгохын төлөө байдаг. Чиний одоо эрэлхийлж буй бүхэн зөвхөн нууцуудад чих тавьж, Бурханы үгийг сонсож, нүдээ хужирлаж, ямар нэг шинэ зүйл, чиг хандлага байгаа эсэхийг харахаар хайж, сониуч зангаа хангах байдаг. Хэрвээ зүрх сэтгэлд чинь иймэрхүү санаа зорилго байгаа бол чи яагаад ч Бурханы шаардлагыг хангаж чадахгүй. Үнэнийг эрэлхийлдэггүй хүмүүс эцсийг нь хүртэл дагаж чадахгүй. Яг одоо, Бурхан ямар нэг зүйл хийхгүй байгаа юм биш, харин хүмүүс Бурханы ажлаас залхсан учраас хамтран ажиллахгүй байгаа юм. Тэд Түүний ерөөл хайрлахаар айлддаг үгийг нь сонсохыг л хүсдэг бөгөөд Түүний шүүлт, гэсгээлтийн үгийг нь сонсохыг хүсдэггүй. Үүний шалтгаан юу вэ? Яагаад гэвэл, хүмүүсийн ерөөл олж авах гэсэн хүсэл биелээгүй учраас тэд идэвхгүй, сул дорой болсон. Бурхан Өөрийг нь дагах боломжийг хүмүүст зориуд олгодоггүй юм биш, мөн хүн төрөлхтөнд зориуд цохилт өгч байгаа ч юм биш. Өөрсдийнх нь санаа зорилго зохисгүй байдаг учраас л хүмүүс идэвхгүй, сул дорой байдаг. Бурхан бол хүнд амь өгдөг Бурхан бөгөөд хүнийг үхэлд хүргэж чадахгүй. Хүмүүсийн сөрөг, сул дорой байдал, ухралт няцалт бүгд өөрсдөөс нь үүдэлтэй.

Бурханы одоогийн ажил нь хүмүүст зарим нэг цэвэршүүлэлт авчирдаг бөгөөд энэхүү цэвэршүүлэлтийг хүлээж авахдаа бат зогсож чаддаг хүмүүс л Бурханы сайшаалыг хүртэнэ. Тэр яаж Өөрийгөө нууж, үг хэлэхгүй, ажиллахгүй байсан ч хамаагүй, чи эрч хүчтэйгээр эрж хайсаар байж чадна. Бурхан чамайг голох болно гэж хэлсэн ч гэсэн чи Түүнийг дагасаар байх болно. Энэ нь Бурханы төлөө гэрчлэлд зогсож байгаа хэрэг юм. Хэрвээ Бурхан чамаас Өөрийгөө нуухад, чи Түүнийг дагахаа боливол энэ нь Бурханы төлөө гэрчлэлд зогсож байгаа хэрэг мөн үү? Хүмүүст бодитой оролт байхгүй бол тэдэнд бодитой биеийн хэмжээ байдаггүй бөгөөд асар том шалгалттай үнэхээр тулгарах үедээ тэд бүдэрдэг. Бурхан үг айлдахгүй, эсвэл чиний үзэлтэй нийцэхгүй зүйл хийж байгаа үед чи сэтгэлээ барьж дийлдэггүй. Хэрвээ Бурхан одоо чиний үзлийн дагуу үйлдэж байсан бол, Тэр чиний хүслийг хангаж, чи босож зогсоод эрч хүчтэйгээр эрэлхийлж чаддаг байсан бол,

чиний түшиглэж амьдардаг үндэс суурь юу байх байсан бэ? Хүний сониуч зангаасаа бүрэн хамааралтай амьдарч байгаа олон хүн байдаг гэж Би хэлнэ. Тэдэнд эрж хайх жинхэнэ зүрх сэтгэл огтоос байдаггүй. Үнэний оролтыг эрэлхийлдэггүй, харин өөрсдийн сониуч занд түшиглэн амьдардаг хүмүүс бол жигшмээр хүмүүс бөгөөд тэд аюулд байдаг! Бурханы янз бүрийн ажил нь бүгд хүн төрөлхтнийг төгс болгохын тулд хэрэгждэг. Гэвч хүмүүс үргэлж сониучирхаж, хов живийн талаар асууж лавлах дуртай байдаг, тэд гадаад орон дахь одоогийн хэрэг явдлын талаар санаа зовж байдаг. Тэд жишээ нь Израилд юу болж байгаа, Египетэд газар хөдлөлт болсон эсэхийг сонирхох зэргээр аминч хүслээ хангах шинэ, сонин хачин зүйлсийг үргэлж хайж байдаг. Тэд амийг эрэлхийлдэггүй, төгс болгуулахыг ч зорьдоггүй. Харин тэдний сайхан мөрөөдөл биелж, хэрээс хэтэрсэн хүслүүд нь гүйцэлдэж магадгүй гэсэндээ Бурханы өдрийг аль болох хурдан ирүүлэхийг л эрж хайдаг. Тийм хүн бол прагматик биш—тэд бол буруу харах өнцөгтэй хүмүүс юм. Үнэнийг эрж хайх л хүн төрөлхтний Бурханд итгэх итгэлийн үндэс суурь мөн. Хүмүүс амийн оролтыг эрэлхийлдэггүй, Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрж хайдаггүй бол шийтгэл хүлээнэ. Шийтгүүлэх хүмүүс бол Бурханы ажлын цаг үед Ариун Сүнсний ажил байхгүй хүмүүс юм.

Бурханы ажлын энэ үе шатанд хүмүүс Түүнтэй хэрхэн хамтран ажиллах ёстой вэ? Бурхан одоогоор хүмүүсийг туршиж байгаа. Тэр үг айлдахгүй, харин Өөрийгөө нууж, хүмүүстэй шууд холбоо тогтоохгүй байгаа. Гаднаас нь харахад Тэр ямар ч ажил хийхгүй байгаа юм шиг боловч үнэндээ бол хүний дотор ажилласаар байгаа. Амийн оролтыг эрэлхийлдэг хэн боловч амийн эрэл хайгуулын үзэгдэлтэй байдаг бөгөөд Бурханы ажлыг бүрэн дүүрэн ойлгодоггүй байсан ч гэсэн тэдэнд эргэлзээ байдаггүй. Шалгалт туулж байхад Бурхан юу хийхийг хүсдэг, Тэр ямар ажил гүйцэлдүүлэхийг хүсдэгийг мэддэггүй байсан ч гэсэн, хүн төрөлхтнийг гэсэн Бурханы санаа зорилго үргэлж сайн байдгийг мэдэх хэрэгтэй. Хэрвээ чи Түүнийг үнэн зүрх сэтгэлээр эрэлхийлдэг бол Тэр чамайг хэзээ ч орхихгүй бөгөөд эцэст нь чамайг гарцаагүй төгс болгож, хүмүүсийг зохих хүрэх газарт нь аваачна. Бурхан одоогоор хүмүүсийг хэрхэн туршиж байгаагаас үл хамааран, Тэр хүмүүсийг зохих үр дүнгээр нь хангаж, хийсэн зүйлд нь үндэслэн зохих залхаан цээрлүүлэлтийг ногдуулах өдөр ирэх болно. Бурхан хүмүүсийг тодорхой нэг цэгт хүртэл хөтлөөд, дараа нь зүгээр л тэднийг хөсөр хаяж, умартахгүй. Учир нь Бурхан бол итгэж болохуйц билээ. Энэ үе шатанд Ариун Сүнс цэвэршүүлэлтийн ажил хийж байна. Тэр хүн нэг бүрийг цэвэршүүлж байгаа. Үхлийн шалгалт болон гэсгээлтийн шалгалтаас бүрдсэн ажлын алхамд, үгээр дамжуулан цэвэршүүлэлтийг хэрэгжүүлсэн. Хүмүүс Бурханы ажлыг туулахын тулд эхлээд Түүний одоогийн ажлыг, мөн хүн төрөлхтөн хэрхэн хамтран ажиллах хэрэгтэйг ойлгох ёстой. Үнэндээ, энэ нь хүн бүрийн ойлгох ёстой зүйл юм. Бурхан юу хийх нь хамаагүй, энэ нь цэвэршүүлэлт байна уу, эсвэл Тэр үг хэлэхгүй ч байсан, Бурханы ажлын нэг ч алхам хүн төрөлхтний үзэлтэй нийцдэггүй. Түүний ажлын алхам бүр хүмүүсийн үзлийг бут цохиж, эвддэг. Энэ бол

Түүний ажил. Гэхдээ, Бурханы ажил тодорхой үе шатанд хүрсэн тул Тэр ямартай ч бүх хүн төрөлхтнийг үхүүлэхгүй гэдэгт чи итгэх ёстой. Тэр хүн төрөлхтөнд амлалт болон ерөөлийн аль алийг нь өгдөг бөгөөд Түүнийг эрэлхийлдэг бүх хүн ерөөлийг нь олж авч чадна, харин тэгдэггүй хүмүүсийг Бурхан таягдан хаяна. Энэ нь чиний эрэл хайгуулаас шалтгаалдаг. Өөр бусад зүйлээс үл хамааран, Бурханы ажил дуусах үед хүн нэг бүр тохирсон хүрэх газартай байх болно гэдэгт чи итгэх ёстой. Бурхан хүн төрөлхтнийг сайхан хүсэл эрмэлзлээр хангасан боловч эрэл хайгуулгүйгээр тэдгээрийг олж авах боломжгүй. Чи одоо үүнийг харж чаддаг байх ёстой—Бурхан хүмүүсийг цэвэршүүлж, гэсгээх нь Түүний ажил, харин хүмүүсийн хувьд цаг үргэлж зан чанарын өөрчлөлтийг эрэлхийлэх ёстой. Бодит туршлагадаа чи эхлээд Бурханы үгийг хэрхэн идэж, уухаа мэдэх ёстой; мөн юу руу орох ёстойгоо болон өөрийн дутагдлыг Түүний үгэн дотроос олж мэдэж, өөрийн бодит туршлагад орохоор эрж хайж, хэрэгжүүлэх учиртай Бурханы үгийн хэсгийг аваад хэрэгжүүлэхээр хичээх ёстой. Бурханы үгийг идэж, уух нь нэгээхэн тал. Мөн түүнчлэн чуулганы амьдралыг хадгалахын сацуу хэвийн сүнслэг амьдралтай байж, одоогийн бүх байдлаа Бурханд өгч чаддаг байх ёстой. Түүний ажил хэрхэн өөрчлөгдөх нь хамаагүй, сүнслэг амьдрал чинь хэвийн хэвээр үлдэх ёстой. Сүнслэг амьдрал чиний хэвийн оролтыг хадгалж чадна. Бурхан юу хийдэг нь хамаагүй, чи сүнслэг амьдралаа тасралтгүй үргэлжлүүлж, үүргээ биелүүлэх учиртай. Энэ бол хүмүүсийн хийх ёстой зүйл. Энэ бүгд нь Ариун Сүнсний ажил боловч хэвийн нөхцөл байдалтай хүмүүсийн хувьд энэ нь төгс болгуулах байхад хэвийн бус нөхцөл байдалтай хүмүүст энэ нь шалгалт юм. Ариун Сүнсний цэвэршүүлэлтийн ажлын одоогийн үе шатанд зарим хүн, Бурханы ажил маш агуу бөгөөд хүмүүст цэвэршүүлэлт маргаангүй хэрэгтэй, эс тэгвээс тэдний биеийн хэмжээ дэндүү жижиг байх бөгөөд тэд Бурханы хүсэлд хүрэх аргагүй байх болно гэж хэлдэг. Гэсэн хэдий ч нөхцөл байдал нь сайн бус хүмүүсийн хувьд энэ нь Бурханыг эрэлхийлэхгүй байх шалтгаан, цугларалтад оролцохгүй байх, Бурханы үгийг идэж, уухгүй байх шалтгаан болдог. Бурханы ажилд Түүний юу хийдэг, ямар өөрчлөлт хийдэг нь хамаагүй хүмүүс хэвийн сүнслэг амьдралын суурийг хадгалах ёстой. Чи сүнслэг амьдралынхаа одоогийн үе шатанд хайнга байгаагүй байж магадгүй боловч, чи ихийг олж аваагүй л байгаа, асар их ургац хураагаагүй байгаа. Иймэрхүү нөхцөлд чи дүрмийг дагах л ёстой; аминдаа хохирол амсахгүйн тулд, Бурханы хүслийг хангахын тулд чи эдгээр дүрмийг мөрдөх ёстой. Хэрвээ сүнслэг амьдрал чинь хэвийн бус бол чи Бурханы одоогийн ажлыг ойлгож чадахгүй харин ч чиний үзэлтэй огт нийцдэггүй гэдгийг чи үргэлж мэдэрдэг ба Түүнийг дагахад бэлэн байдаг ч чамд дотоод хөдөлгөгч хүч дутагддаг. Иймээс Бурхан одоо юу хийж байгаа нь хамаагүй, хүмүүс хамтран ажиллах ёстой. Хэрвээ хүн хамтран ажилладаггүй бол Ариун Сүнс ажлаа хийж чадахгүй, хэрвээ хүмүүст хамтран ажиллах зүрх сэтгэл байхгүй бол Ариун Сүнсний ажлыг олж авч бараг чадахгүй. Хэрвээ чи Ариун Сүнсний ажлыг өөрийн дотор байлгахыг, Бурханы сайшаалыг олж авахыг хүсэж байвал Бурханы

өмнө анхны үнэнч байдлаа хадгалах ёстой. Одоо чи илүү гүнзгий ойлголт, илүү дээд зэргийн онол, өөр бусад иймэрхүү зүйлтэй байх шаардлагагүй—анхдагч суурин дээр Бурханы үгийг баримтлах нь л шаардлагатай бүх зүйл юм. Хэрвээ хүмүүс Бурхантай хамтарч ажилладаггүй, гүнзгий оролтыг эрэлхийлдэггүй бол тэдэнд анх байсан бүх зүйлийг Бурхан булаан авна. Хүмүүс дотроо тав тухтай байдалд үргэлж шунадаг ба хэдийн байгаа зүйлийг эдлэхийг илүүд үздэг. Тэд ямар ч төлөөс төлөхгүйгээр Бурханы амлалтыг олж авахыг хүсдэг. Энэ бол хүн төрөлхтний тээдэг хэрээс хэтэрсэн бодол юм. Төлөөс төлөхгүйгээр амь олж авах—гэвч аливаа зүйл ийм амархан байсан гэж үү? Хүн Бурханд итгэж, амийн оролтыг эрж хайж, зан чанарын өөрчлөлтийг эрж хайх үедээ төлөөс төлж, Бурхан юу ч хийсэн, Түүнийг үргэлж дагах байдалд хүрэх ёстой. Энэ бол хүмүүсийн хийх ёстой зүйл юм. Чи энэ бүхнийг дүрэм болгож дагадаг ч гэсэн үүнийг үргэлж баримтлах ёстой бөгөөд шалгалтууд хэчнээн их байх нь хамаагүй Бурхантай харилцах хэвийн харилцаагаа орхиж болохгүй. Чи залбирч, чуулганы амьдралаа хадгалж, мөн ах эгч нараа хэзээ ч орхихгүй байж чадах ёстой. Бурхан чамайг шалгахад чи үнэнийг эрж хайсаар байх ёстой. Энэ бол сүнслэг амьдралын хамгийн наад захын шаардлага юм. Үргэлж эрж хайх хүсэлтэй байж, хамтран ажиллахыг мэрийж, бүх эрч хүчээ ашиглах—үүнийг хийх боломжтой юу? Хүмүүс үүнийг үндэс сууриа болговол тэд ялган таних чадвар, бодит байдлын оролтод хүрнэ. Өөрийн чинь байдал хэвийн байх үед Бурханы үгийг хүлээн зөвшөөрөхөд амархан байдаг; энэ нөхцөл байдалд үнэнийг хэрэгжүүлэхэд хэцүү санагддаггүй, Бурханы ажил агуу гэдгийг чи мэдэрдэг. Гэвч нөхцөл байдал чинь тааруу байвал Бурханы ажил хэчнээн агуу байсан, хэн нэгэн хэчнээн сайхан ярьдаг байсан ч, чи анхаарал хандуулахгүй. Хүний нөхцөл байдал хэвийн бус байх үед Бурхан тэдний дотор ажиллаж чадахгүй бөгөөд тэд зан чанарын өөрчлөлтөд хүрч чадахгүй.

Хэрвээ хүмүүс ямар ч итгэлгүй байвал энэ замаар үргэлжлүүлэхэд амаргүй. Бурханы ажил хүмүүсийн үзэл, төсөөлөлтэй өчүүхэн ч нийцдэггүй гэдгийг хүн бүхэн одоо харж чадна. Бурхан маш олон үг айлдаж, маш их ажил хийсэн бөгөөд хэдий хүмүүс тэдгээрийг үнэн гэж хүлээн зөвшөөрч болох ч, Бурханы талаарх үзэл тэдний дотор бий болох магадлалтай хэвээр байна. Хэрэв үнэнийг ойлгож, олж авахыг хүсвэл, хүмүүс аль хэдийн харсан зүйл болон туршлагаараа олж авсан зүйлдээ үнэнч байж чадах итгэлтэй, сэтгэлийн тэнхээтэй байх ёстой. Бурхан хүмүүст юу хийдэг нь хамаагүй, тэд өөрсдийн эзэмшдэг зүйлийг баримталж, Бурханы өмнө чин сэтгэлтэй байж, эцсээ хүртэл Түүнд үнэнч хэвээр байх ёстой. Энэ бол хүн төрөлхтний үүрэг. Хүмүүс хийх ёстой зүйлээ баримтлах ёстой. Бурханд итгэх итгэл нь Түүнд дуулгавартай байж, Түүний ажлыг туулахыг шаарддаг. Бурхан маш их ажил хийсэн—хүмүүсийн хувьд энэ нь бүгд төгс болголт, цэвэршүүлэлт, түүнээс ч илүүтэйгээр гэсгээлт гэж хэлж болох юм. Хүний үзэлтэй нийцсэн Бурханы ажлын нэг ч алхам байгаагүй; хүмүүсийн эдэлсэн зүйл бол Бурханы хатуу үг юм. Бурханыг ирэх үед хүмүүс Түүний сүр жавхлан, уур хилэнг эдлэх ёстой. Гэхдээ Түүний үг

хэчнээн хатуу байх нь хамаагүй, Тэр хүн төрөлхтнийг аварч, төгс болгохоор ирдэг. Бүтээгдсэн зүйлийн хувьд хүмүүс биелүүлэх ёстой үүргээ биелүүлж, цэвэршүүлэлт дунд Бурханы төлөө гэрчлэлд зогсох ёстой. Шалгалт бүрд тэд гэрчлэх ёстой гэрчлэлээ баримталж, Бурханы төлөө цангинасан гэрчлэл хийх ёстой. Үүнийг хийдэг хүн бол ялагч юм. Бурхан чамайг хэрхэн цэвэршүүлэх нь хамаагүй, чи итгэл дүүрэн хэвээр байж, Бурханд итгэх итгэлээ хэзээ ч алддаггүй. Чи хүний хийх ёстой зүйлийг хийдэг. Энэ бол хүнээс Бурханы шаарддаг зүйл бөгөөд хүний зүрх сэтгэл Түүн рүү бүрмөсөн эргэн ирж, өнгөрөн одох хором бүрд Түүн рүү эргэж чаддаг байх ёстой. Энэ бол ялагч юм. “Ялагч” гэж Бурханы нэрлэдэг хүмүүс нь Сатаны нөлөөн дор, Сатаны бүслэлтэд байхдаа, өөрөөр хэлбэл, харанхуйн хүчний дунд байх үедээ гэрчлэлд зогсож, итгэлээ хадгалж, Бурханд үнэнч байдлаа хадгалж чадсаар байдаг хүмүүс юм. Юу ч болж байсан, чи Бурханы өмнө цэвэр ариун зүрх сэтгэлээ хадгалж, Бурханыг хайрлах жинхэнэ хайраа хадгалж чадсаар байдаг бол Бурханы өмнө гэрчлэлд зогсож байгаа бөгөөд үүнийг Бурхан “ялагч” байх гэж нэрлэдэг. Бурхан чамайг ерөөх үед эрэл хайгуул чинь гойд сайн байдаг боловч Түүний ерөөл байхгүй үед ухарч няцдаг бол энэ нь цэвэр ариун байдал мөн үү? Энэ зам нь үнэн гэдэгт итгэлтэй байгаа л бол чи эцсийг нь хүртэл дагах ёстой; чи Бурханд үнэнч байдлаа хадгалах ёстой. Чамайг төгс болгохын тулд Бурхан Өөрөө газар дээр ирсэн гэдгийг харсан болохоор чи зүрх сэтгэлээ Түүнд бүхлээр нь өгөх ёстой. Тэр юу хийдэг нь хамаагүй, бүр эцэст нь чамд тааламжгүй үр дүн товлосон ч гэсэн чи Түүнийг дагасаар байж чаддаг бол энэ нь Бурханы өмнө цэвэр ариун байдлаа хадгалж буй хэрэг юм. Ариун сүнслэг бие болон ариун онгон охиныг Бурханд өргөх нь Бурханы өмнө чин сэтгэлээ хадгалж байгаа гэсэн үг билээ. Хүн төрөлхтний хувьд чин сэтгэл бол цэвэр ариун байдал бөгөөд Бурханд чин сэтгэлээсээ хандаж чаддаг байх нь цэвэр ариун байдлыг хадгалж байгаа хэрэг юм. Энэ бол чиний хэрэгжүүлэх ёстой зүйл. Чи залбирах ёстой үедээ залбир; нөхөрлөхөөр цуглах ёстой үедээ цуглар; магтан дуу дуулах ёстой үедээ магтан дуу дуул; мөн махан биеийг хаях ёстой үедээ махан биеийг хая. Үүргээ гүйцэтгэх үедээ аргацааж бүү хий; шалгалттай тулгарах үедээ бат зогс. Энэ бол Бурханд үнэнч байх юм. Хэрвээ чи хүмүүсийн хийх ёстой зүйлийг баримталдаггүй бол өмнөх бүх зовлон, шийдвэр чинь хий дэмий болох болно.

Бурханы ажлын үе шат бүрд хүмүүсийн хамтран ажиллах ёстой арга зам байдаг. Бурхан хүмүүсийг цэвэршүүлдэг болохоор цэвэршүүлэлт туулахдаа тэд итгэлтэй байдаг. Бурхан хүмүүсийг төгс болгодог болохоор тэд Бурханаар төгс болгуулах итгэлтэй байж, Түүний цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрөхөд, Бурханы харьцалт, засалтад бэлэн байдаг. Хүмүүст гэгээрэл, гэрэлтүүлэлт авчирч, Өөртэйгөө хамтран ажиллуулж, хэрэгжүүлүүлэхийн тулд Бурханы Сүнс хүмүүсийн дотор ажилладаг. Бурхан цэвэршүүлэлтийн үеэр ярьдаггүй. Тэр Өөрийн дуу хоолойгоор айлддаггүй боловч хүмүүсийн хийх ёстой ажил байж л байгаа. Чи өөрт хэдийн байгаа зүйлийг баримтлах ёстой, чи Бурханд залбирч, Бурхантай ойр байж,

Бурханы өмнө гэрчлэлд зогсож чадсаар байх ёстой; ийм маягаар чи үүргээ биелүүлнэ. Хүмүүсийн итгэл болон хайрыг шалгах Бурханы шалгалтууд нь Түүнд илүү их залбирч, Бурханы өмнө Түүний үгийг илүү их амтлахыг шаарддаг гэдгийг та бүхэн Түүний ажлаас тодорхой харах хэрэгтэй. Бурхан чамайг гэгээрүүлж, Өөрийн хүслийг чамд ойлгуулдаг боловч чи үүний алийг нь ч хэрэгжүүлдэггүй бол юу ч олж авахгүй. Бурханы үгийг хэрэгжүүлэх үедээ чи Түүнд залбирч чадсаар байх ёстой бөгөөд Түүний үгийг амтлах үедээ Түүний өмнө ирж, эрж хайж, урам хугаралт, хүйтэн сэтгэлийн ямар ч ул мөргүйгээр Түүнд итгэх итгэлээр дүүрэн байх ёстой. Бурханы үгийг хэрэгжүүлдэггүй хүмүүс цугларалтын үеэр эрч хүчээр дүүрэн байдаг боловч гэртээ харих үедээ харанхуйд унадаг. Хамт цуглахыг хүртэл хүсдэггүй зарим хүн бий. Иймээс хүмүүс ямар үүрэг биелүүлэх ёстойг чи тодорхой ойлгох ёстой. Бурханы хүсэл чухам юу болохыг чи мэдэхгүй байж болох боловч үүргээ гүйцэтгэж, залбирах ёстой үедээ залбирч, үнэнийг хэрэгжүүлэх ёстой үедээ хэрэгжүүлж, хүмүүсийн хийх ёстой зүйлсийг хийж чадна. Чи анхны үзэгдлээ баримталж чадна. Ийм маягаар Бурханы ажлын дараагийн алхмыг хүлээн зөвшөөрөх илүү боломжтой болно. Бурхан нуугдмал байдлаар ажиллах үед чи эрж хайдаггүй бол энэ нь асуудал болдог. Цугларалтуудын үеэр Түүнийг ярьж, номлох үед чи урам зоригтойгоор сонсдог ч Түүнийг ярихгүй байх үед чи эрч хүчээр дутаж, ухарч няцдаг. Ямар төрлийн хүн ингэдэг вэ? Энэ бол ердөө л урсгалаараа явдаг хүн юм. Тэд ямар ч үзэл баримтлал, гэрчлэл, үзэгдэлгүй байдаг! Ихэнх хүмүүс ийм байдаг. Хэрвээ ийм маягаар үргэлжлүүлбэл нэг л өдөр асар том шалгалт ирэх үед чи шийтгэлд унах болно. Үзэл баримтлалтай байх нь Бурхан хүмүүсийг төгс болгох явцад маш чухал байдаг. Хэрвээ чи Бурханы ажлын нэг ч үе шатанд эргэлздэггүй, хүний үүргийг биелүүлж, Бурханы чамаар хэрэгжүүлүүлдэг зүйлийг чин сэтгэлээсээ баримталдаг бол, өөрөөр хэлбэл, Бурханы захиасыг санаж, Тэр өнөө үед юу ч хийдэг байсан Түүний захиасыг мартдаггүй бол, Түүний ажилд эргэлздэггүй, үзэл баримтлалаа хадгалж, гэрчлэлээ баримталж, алхам алхмаар ялалтад хүрдэг бол эцэст нь чи Бурханаар төгс болгуулж, ялагч болгуулах болно. Хэрвээ чи Бурханы шалгалтуудын алхам бүрд бат зогсож чаддаг, эцсийг нь хүртэл бат зогсож чаддаг бол чи бол ялагч, Бурханаар төгс болгуулсан нэгэн юм. Хэрвээ чи одоогийн шалгалтуудад бат зогсож чадахгүй бол ирээдүйд бүр ч илүү хэцүү болно. Хэрвээ чи зөвхөн шалихгүй зовлон туулаад, үнэнийг эрэлхийлдэггүй бол эцэст нь юу ч олж авахгүй, гар хоосон үлдэх болно. Бурхан ярихгүй байгааг хараад эрэл хайгуулаа орхиж, зүрх сэтгэл нь сарнидаг зарим хүн байдаг. Ийм хүн мунхаг бус уу? Иймэрхүү хүмүүст ямар ч бодит байдал байдаггүй. Бурханыг ярихад тэд үргэлж ийш тийш гүйж, гаднаа завгүй, урам зоригтой харагдах боловч Бурхан одоо ярихгүй байгаа болохоор тэд эрж хайхаа больдог. Ийм хүн ирээдүйгүй. Цэвэршүүлэлтийн үеэр чи эерэг харах өнцгөөс орж, сурах ёстой хичээлүүдээ сурч мэдэх ёстой; Бурханд залбирч, Түүний үгийг уншихдаа өөрийн байдлыг үүнтэй харьцуулж, дутагдлаа олж нээж, сурах хичээл чамд маш олон байгааг олж мэдэх ёстой. Цэвэршүүлэлт

туулахдаа чин сэтгэлээсээ эрж хайх тусмаа өөрийгөө хангалтгүй гэдгээ төдий чинээ их олж мэднэ. Цэвэршүүлэлт туулж байх үед чамд олон асуудал тулгардаг; чи тэдгээрийг тодорхой харж чадахгүй, гомдоллож, махан биеэ илчилдэг—ийм маягаар л чиний дотор завхарсан зан чанар дэндүү олон байгааг олж нээж чадна.

Хүмүүст хэв чанар дутмаг байдаг ба Бурханы стандартаас хэтэрхий хол зөрөөтэй байдаг. Ирээдүйд энэ замаар явахад тэдэнд итгэлтэй байдал бүр ч их хэрэгтэй байж магадгүй. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил үлэмж их итгэлийг, Иовын итгэлээс ч илүү агуу их итгэлтэй байдлыг шаарддаг. Итгэлтэй байдалгүйгээр хүмүүс үргэлжлүүлэн туршлагажиж чадахгүй бөгөөд Бурханаар төгс болгуулж бас чадахгүй. Агуу шалгалтын өдөр ирэхэд чуулганuудыг орхих хүмүүс хаа сайгүй байх болно. Урьдын өдрүүдэд эрж хайхдаа маш сайн байсан зарим хүн байх бөгөөд яагаад тэд итгэхээ больсон нь тодорхойгүй байх болно. Чиний ойлгохгүй олон зүйл тохиолдох бөгөөд Бурхан бас ямар ч тэмдэг, гайхамшиг үзүүлэхгүй, ямар ч ер бусын зүйл хийхгүй. Энэ нь баттай зогсож чадах эсэхийг чинь харахын тулд байдаг—Бурхан хүмүүсийг цэвэршүүлэхдээ баримтууд ашигладаг. Чи хараахан их зовоогүй байна. Ирээдүйд агуу шалгалтууд ирэх үед зарим газарт бүх хүн чуулганыг орхих ба чиний сайн харилцаатай байсан хүмүүс явж, итгэл үнэмшлээ орхино. Чи тэр үед бат зогсож чадах уу? Одоог хүртэл чамд тулгарсан шалгалтууд өчүүхэн байсан бөгөөд магадгүй чи тэдгээрийг арай ядан тэсвэрлэсэн байх. Энэ алхамд зөвхөн үгээр дамжуулсан цэвэршүүлэлт болон төгс болголт хамаардаг. Дараагийн алхамд, чамайг цэвэршүүлэхийн тулд баримт чам дээр ирж, тэгээд чи аюул эрсдэл дунд байх болно. Энэ нь үнэхээр ноцтой болмогц Бурхан чамд яаравчлан явахыг зөвлөх бөгөөд шашны хүмүүс чамайг урхидаж авч явахыг оролдоно. Энэ нь замаа үргэлжлүүлж чадах эсэхийг чинь харахын төлөө байдаг бөгөөд энэ бүгд нь шалгалт юм. Одоогийн шалгалтууд бага боловч зарим гэр бүлийн эцэг эх нь итгэхээ больж, зарим гэр бүлийн хүүхдүүд нь итгэхээ болих өдөр ирэх болно. Чи үргэлжлүүлж чадах уу? Чамайг урагшлах тусам шалгалтууд төдий чинээ том болох болно. Бурхан хүмүүсийн хэрэгцээ болон биеийн хэмжээнийх нь дагуу цэвэршүүлэх ажлаа гүйцэтгэдэг. Бурхан хүн төрөлхтнийг төгс болгох үе шатанд хүмүүсийн тоо үргэлжлэн өсөх боломжгүй—зөвхөн цөөрнө. Эдгээр цэвэршүүлэлтээр л дамжуулан хүмүүс төгс болгуулж чадна. Харьцалт, сахилгажуулалт, туршилт, гэсгээлт, хараагдалт—энэ бүхнийг чи тэсвэрлэж чадах уу? Ах эгч нар нь бүгд асар их эрч хүчтэйгээр эрж хайж байгаа, онцгойлон сайн нөхцөл байдалд байгаа чуулганыг харах үедээ, чи өөрөө зоригждог. Тэд нар бүгд явж, зарим нь итгэхээ больж, зарим нь бизнес хийхээр, эсвэл гэрлэхээр явж, зарим нь шашинд элсчихсэн байх өдөр ирэх үед чи бат зогсож чадах уу? Чи дотроо нөлөөнд нь автахгүй үлдэж чадах уу? Бурхан хүн төрөлхтнийг төгс болгох нь тийм ч амар зүйл биш! Тэр хүмүүсийг цэвэршүүлэхийн тулд олон зүйлийг ашигладаг. Хүмүүс эдгээрийг арга барил гэж үздэг боловч Бурханы анхдагч санаа зорилгоор бол эдгээр нь арга барил огт биш, харин баримт юм. Эцэст нь Тэр хүмүүсийг тодорхой хэмжээнд

цэвэршүүлж, тэд ямар ч гомдолгүй болох үед, Түүний ажлын энэхүү үе шат дуусах болно. Ариун Сүнсний агуу ажил бол чамайг төгс болгох явдал бөгөөд Тэр ажиллахгүй, Өөрийгөө нуух үед энэ нь чамайг төгс болгох бүр ч илүү зорилготой, ялангуяа ийм маягаар хүмүүст Бурханыг гэх хайр байгаа эсэх, Түүнд үнэхээр итгэлтэй байдаг эсэхийг харж болно. Бурхан илэн далангүй ярих үед чи хайх хэрэггүй байдаг; Түүнийг нуугдах үед л чи эрж хайж, тэмтчин урагшлах хэрэгтэй. Чи бүтээгдсэн зүйлийн үүргийг биелүүлж чаддаг байх ёстой, ирээдүйн үр дүн болон хүрэх газар чинь ямар ч байлаа гэсэн, амьд байх хугацаандаа Бурханы талаарх мэдлэг, Бурханыг гэх хайрыг эрэлхийлж чаддаг байх ёстой, мөн Бурхан чамд яаж ч ханддаг байсан, гомдоллохоос зайлсхийж чаддаг байх ёстой. Ариун Сүнс хүмүүсийн дотор ажиллахад нэг болзол байдаг. Тэд цангаж, эрж хайж, Бурханы үйлдлийн талаар хайнга биш, эргэлзэхгүй байж, цаг үргэлж өөрсдийн үүргийг сахин биелүүлж чадах ёстой; зөвхөн ингэж байж л Ариун Сүнсний ажлыг олж авч чадна. Бурханы ажлын алхам бүрд хүн төрөлхтнөөс шаарддаг зүйл бол үлэмж их итгэлтэй байдал, эрж хайхын тулд Бурханы өмнө ирэх юм—туршлагаар л дамжуулан хүмүүс Бурхан хэчнээн хайр татам болохыг, Ариун Сүнс хүмүүст хэрхэн ажилладгийг олж мэдэж чаддаг. Хэрвээ чи туршлагаждаггүй бол, тэмтчин урагшилдаггүй бол, эрж хайдаггүй бол юу ч олж авахгүй. Чи туршлагаараа дамжуулан тэмтчин урагшлах ёстой бөгөөд өөрийн туршлагаар л дамжуулан Бурханы үйлдлийг харж, Түүний гайхалтай, ойлгошгүй байдлыг танин мэдэж чадна.

ЧИ АМИЛСАН ХҮН МӨН ҮҮ?

Завхарсан зан чанараа хаяж, хэвийн хүн чанарыг амьдран харуулдаг болсон үедээ л чи төгс болгуулна. Чи зөгнөл хэлж чадахгүй, аливаа нууцын тухай ярьж чадахгүй боловч хүний дүрийг амьдран харуулж, илчилнэ. Хүнийг Бурхан бүтээсэн боловч дараа нь Сатан тэднийг завхруулснаар тэд “үхмэл хүмүүс” болсон юм. Иймээс өөрчлөгдсөнийхөө дараа чи эдгээр “үхмэл хүмүүс” шиг байхаа болино. Бурханы үг л хүмүүсийн сүнсийг сэхээж, тэднийг дахин төрүүлдэг бөгөөд хүмүүсийн сүнс дахин төрөх үед тэд амилсан байх болно. “Үхмэл хүмүүс” гэж ярих үедээ Би сүнсгүй цогцос болон сүнс нь дотроо үхсэн хүмүүсийг хэлж байгаа юм. Хүмүүсийн сүнсийг амийн очоор сэхээх үед тэд амилдаг. Урьд нь ярьж байсан ариун хүмүүс гэдэг нь амилсан хүмүүс буюу Сатаны эзэмшил дор байсан ч Сатаныг ялсан хүмүүсийг хэлдэг. Хятадын сонгогдсон хүмүүс агуу улаан лууны харгис, балмад хавчлага, заль мэхийг амссанаасаа болж сэтгэл санаагаар сүйрч, амьдрах өчүүхэн ч эр зориггүй болж орхисон. Иймээс, тэдний сүнсийг мөн чанараас нь эхлэн сэрээх ёстой: Бага багаар, мөн чанар дотроо тэдний сүнс сэрэх ёстой. Нэг л өдөр тэднийг амилах үед саад тотгор гэж байхаа больж, бүх зүйл төвөггүй урагшлах болно. Одоогоор энэ нь биелэх аргагүй хэвээр байна. Ихэнх хүн амьдралын хэв маягаараа

үхлийн уур амьсгалыг ихээр амьдран харуулдаг, тэд үхлийн аурагаар хүрээлэгдсэн байдаг ба хэтэрхий их зүйлээр дулимаг байдаг. Зарим хүний үг нь үхэл дагуулж, үйлдэл нь үхэл тээн, амьдран харуулдаг бараг бүх зүйл нь үхлээс бүрдсэн байдаг. Өнөөдөр хүмүүс Бурханд ил тод гэрчлэл хийвэл бүтэлгүйтэх болно, учир нь тэд бүрэн амилах болоогүй, бас та нарын дунд асар олон үхдэл бий. Өнөөдөр зарим хүн, Бурхан Харь үндэстэн дунд ажлаа хурдан түгээхийн тулд яагаад тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй юм бэ гэж асуудаг. Үхэгсэд Бурханд гэрчлэл хийж чаддаггүй; энэ нь амьд хүмүүсийн л чаддаг зүйл боловч өнөөдрийн ихэнх хүн “үхмэл хүмүүс” юм, тэд асар олуулаа үхлийн нөмрөг, Сатаны нөлөөн дор амьдардаг бөгөөд ялалтыг олж авах чадваргүй. Тэгэхээр тэд яаж Бурханд гэрчлэл хийж чадах юм бэ? Тэд яаж сайн мэдээний ажлыг түгээж чадах юм бэ?

Харанхуйн нөлөөн дор амьдардаг хүмүүс бол үхэл дунд амьдардаг, Сатанд эзэмдүүлсэн хүмүүс юм. Хүмүүс Бурханаар аврагдаж, Бурханаар шүүгдэж, гэсгээгдэлгүйгээр үхлийн нөлөөнөөс зугтаж чадахгүй, амьд болж чадахгүй. Энэ “үхмэл хүмүүс” Бурханд гэрчлэл хийж чаддаггүй, Бурханд ашиглагдаж ч чаддаггүй, хаанчлалд орж бүр ч чадахгүй. Бурхан үхэгсдийн бус, амьд хүмүүсийн гэрчлэлийг хүсдэг ба үхэгсдээс бус, амьд хүмүүсээс Өөрийнх нь төлөө ажиллахыг шаарддаг. “Үхэгсэд” бол Бурханыг эсэргүүцэн тэрсэлдэг хүмүүс юм; тэд бол сүнс нь мэдрэлгүй бөгөөд Бурханы үгийг ойлгодоггүй хүмүүс, үнэнийг хэрэгжүүлдэггүй, Бурханд өчүүхэн төдий ч үнэнч биш, мөн Сатаны эзэмшил дор амьдарч, Сатанд ашиглагддаг хүмүүс юм. Үхэгсэд үнэний эсрэг зогсож, Бурханы эсрэг тэрслэн, дорд, жигшүүрт, хорон, хэрцгий, зальхай, муу санаатай байснаараа өөрсдийгөө харуулдаг. Ийм хүмүүс Бурханы үгийг идэж уусан ч гэсэн Бурханы үгийг амьдран харуулж чаддаггүй; тэд амьд боловч алхаж буй үхдэлүүд, амьсгалдаг цогцсууд юм. Үхэгсэд Бурханыг сэтгэл хангалуун байлгах ямар ч чадваргүй бөгөөд Түүнд бүрэн дүүрэн дуулгавартай байж бүр ч чаддаггүй. Тэд ердөө л Түүнийг мэхэлж, доромжилж, Түүнээс урваж чаддаг бөгөөд амьдран харуулдаг бүх хэв маягаараа Сатаны уг чанарыг илчилдэг. Хүмүүс амьд хүн болж, Бурханд гэрчлэл хийж, Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхийг хүсвэл Бурханы авралыг хүлээн зөвшөөрөх ёстой; Түүний шүүлт, гэсгээлтэд баяртайгаар захирагдах ёстой, мөн Бурханы засалт, харьцалтыг баяртайгаар хүлээн авах ёстой. Тэр үед л тэд Бурханы шаарддаг бүх үнэнийг хэрэгжүүлэх чадвартай болно, тэр үед л тэд Бурханы авралыг олж авч, үнэхээр амьд хүн болох болно. Амьд хүмүүс бол Бурханаар аврагдсан хүмүүс, тэд Бурханаар шүүгдэж, гэсгээгдсэн бөгөөд өөрсдийгөө зориулахад бэлэн байдаг, амиа Бурханд дуртайяа өгч, бүхий л амьдралаа Бурханд баяртайгаар зориулдаг. Амьд хүмүүс Бурханд гэрчлэл хийх үед л Сатан шившиглэгдэнэ, амьд хүмүүс л Бурханы сайн мэдээний ажлыг түгээж чадна, амьд хүмүүс л Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадна, амьд хүмүүс л жинхэнэ хүн юм. Анх Бурханы бүтээсэн хүн амьд байсан боловч Сатаны завхралын улмаас хүн үхлийн дунд, Сатаны нөлөөн дор амьдардаг, иймээс хүмүүс сүнсгүй үхэгсэд болсон, Бурханыг эсэргүүцдэг дайснууд болсон, Сатаны хэрэгсэл

болсон, мөн Сатаны хоригдол болцгоосон. Бурханы бүтээсэн бүх амьд хүн үхдэл болсон учраас Бурхан гэрчлэлээ алдсан, мөн Тэр Өөрийнхөө бүтээсэн, Өөрийнх нь амьсгалыг агуулдаг цорын ганц зүйл болох хүн төрөлхтнийг алдсан юм. Бурхан гэрчлэлээ буцаан авч, Өөрийнх нь гараар бүтээгдсэн боловч Сатанд олзлогдсон хүмүүсийг буцааж авъя гэвэл тэднийг амьд хүн болгохын тулд дахин амилуулах ёстой, тэгээд Тэр тэднийг гэрэлдээ амьдруулахын тулд буцаан авах ёстой. Үхэгсэд бол сүнсгүй, туйлын хөшүүн, Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм. Хамгийн гол нь тэд бол Бурханыг мэддэггүй хүмүүс. Энэ хүмүүс Бурханд дуулгавартай байх өчүүхэн төдий ч санаа зорилгогүй, зөвхөн Түүний эсрэг тэрсэлж, Түүнийг эсэргүүцдэг ба өчүүхэн ч үнэнч сэтгэлгүй байдаг. Амьд хүмүүс бол сүнс нь дахин төрсөн, Бурханд дуулгавартай байхаа мэддэг, Бурханд үнэнч хүмүүс юм. Тэд үнэн болон гэрчлэлийг эзэмшдэг бөгөөд энэ хүмүүс л Бурханы гэрт Түүний таалалд нийцдэг. Бурхан амилж, авралыг нь харж, Өөрт нь үнэнч байж чадах, Өөрийг нь эрж хайхыг хүсдэг хүмүүсийг авардаг. Тэрээр бие махбодтой болсон Бурханд болон Түүний илрэлтэд итгэдэг хүмүүсийг авардаг. Зарим хүн амилж чаддаг бол зарим нь чаддаггүй; уг чанар нь аврагдаж чадах эсэхээс энэ нь шалтгаалдаг. Олон хүн Бурханы үгээс ихийг сонссон атлаа Бурханы хүслийг ойлгодоггүй, тэдгээрийг хэрэгжүүлэх ч чадваргүй байдаг. Тэр хүмүүс ямар ч үнэнийг амьдран харуулах чадваргүй бөгөөд Бурханы ажилд мөн санаатайгаар саад учруулдаг. Тэд Бурханы төлөө ямар ч ажил хийх чадваргүй, Түүний төлөө юу ч зориулж чаддаггүй, мөн нууцаар чуулганы мөнгийг үрж, Бурханы гэрт үнэгүй хооллодог. Энэ хүмүүс бол үхдэлүүд, тэд аврагдахгүй. Бурхан Өөрийнх нь ажлын дунд байгаа бүх хүнийг авардаг хэдий ч Бурханы авралыг хүлээж авч чаддаггүй нэг хэсэг хүн бий; цөөн тооны хүн л Түүний авралыг хүлээн авч чадна. Учир нь ихэнх хүн хэтэрхий гүн завхарч, үхдэл болсон ба тэд аврагдах аргагүй; тэднийг Сатан бүрэн ашигласан, тэдний уг чанар дэндүү хорлонтой. Мөн тэрхүү цөөн тооны хүн ч Бурханд бүрэн дуулгавартай байж чаддаггүй. Тэд анхнаасаа Бурханд туйлын үнэнч, туйлын хайртай байсан хүмүүс биш; харин тэд Бурханы байлдан дагуулах ажлаас болж дуулгавартай болсон, Бурханы дээдийн дээд хайраас болж Бурханыг хардаг, Бурханы зөвт зан чанараас болж тэдний зан чанарт өөрчлөлт гардаг, мөн Бурханы бодитой агаад энгийн ажлаас болж Бурханыг мэдэж авдаг юм. Бурханы энэ ажилгүйгээр энэхүү хүмүүс хэчнээн ч сайн байсан, Сатан болон үхэлд харьяалагдсан хэвээр, үхсэн хэвээр байх байсан. Өнөөдөр энэ хүмүүс Бурханы авралыг хүлээж авч чаддаг нь гагцхүү тэд Бурхантай хамтран ажиллахыг хүсдэгийнх юм.

Амьд хүмүүс Бурханд үнэнч байдгаасаа үүдэн Бурханаар авхуулж, Түүний амлалт дунд амьдрах болно, харин үхэгсэд Бурханыг эсэргүүцдэгээсээ болж Бурханаар жигшигдэн гологдож, Түүний шийтгэл болон хараалын дунд амьдрах болно. Энэ бол Бурханы зөвт зан чанар бөгөөд ямар ч хүн үүнийг өөрчлөх аргагүй. Хүмүүс өөрсдийнхөө эрэл хайгуулаас үүдэн Бурханы сайшаалыг хүртэж, гэрэлд амьдардаг; овжин явуулгынхаа улмаас хүмүүс Бурханаар хараагдаж, шийтгэл дунд

буудаг; муу үйлээсээ болж хүмүүс Бурханаар шийтгэгддэг; мөн хүсэл тэмүүлэл болон үнэнч зангаасаа болж хүмүүс Бурханы ерөөлийг хүртдэг. Бурхан бол зөвт: Тэр амьд хүмүүсийг ерөөж, үхэгсдийг хараадаг, ингэснээр тэд үргэлж үхэл дунд байж, Бурханы гэрэлд дахин хэзээ ч амьдрахгүй. Бурхан амьд хүмүүсийг Өөртэйгөө үүрд хамт байлгахаар хаанчлал, ерөөл рүүгээ аваачна. Харин үхэгсдийг Тэр нам цохиж, мөнхийн үхэл рүү хүргэнэ; тэд бол Түүний сүйрлийн бай бөгөөд үргэлжид Сатанд харьяалагдана. Бурхан хэнд ч шударга бус ханддаггүй. Бурханыг үнэхээр эрж хайдаг бүхэн Бурханы гэрт үлдэж, Бурханд дуулгаваргүй, таарамжгүй бүхэн Түүний шийтгэл дунд амьдрах нь гарцаагүй. Магадгүй, чи Бурханы махбод дахь ажилд эргэлзэж байж болох юм—гэвч нэг л өдөр Бурханы махбод хүний төгсгөлийг шууд зохицуулахгүй; харин Түүний Сүнс хүний хүрэх газрыг зохицуулах болно, тэр үед хүмүүс Бурханы махбод болон Түүний Сүнс нэг юм, Түүний махбод алдаа гаргадаггүй бөгөөд Түүний Сүнс алдаа гаргах бүр ч боломжгүй юм гэдгийг мэдэх болно. Эцэст нь Тэр амилсан хүмүүсийг нэг ч илүү, дутуугүйгээр хаанчлалдаа аваачна. Харин амилаагүй үхэгсдийг бол Сатаны үүр луу хаяна.

ЗАН ЧАНАР ЧИНЬ ӨӨРЧЛӨГДӨХГҮЙ БАЙХ НЬ БУРХАНД ДАЙСАГНАЖ БУЙ ХЭРЭГ

Хэдэн мянган жилийн завхралын дараа хүн хөшүүн, мулгуу болжээ; Бурханд тэрслүү байдал нь түүхийн хуудаснаа тэмдэглэгдэж, хүн өөрөө ч тэрслүү үйлдлүүдээ бүгдийг нь өчиж барахааргүй хэмжээнд тултлаа Бурханыг эсэргүүцдэг чөтгөр болсон юм. Учир нь Сатан хүнийг гүн завхруулж, хаашаа эргэхээ мэдэхгүй болтол нь төөрүүлсэн. Хүн өнөөдөр ч Бурханаас урвасаар байна: Бурханыг хараад ч урвадаг, Бурханыг харж чадахгүй байхдаа ч мөн л урвадаг. Бурханы хараал, уур хилэнг нүдээр үзсэнийхээ дараа ч гэсэн Түүнээс урвадаг хүмүүс хүртэл бий. Иймээс хүний эрүүл ухааны анхдагч чиг үүрэг нь алдагдаж, мөс чанарынх нь анхдагч чиг үүрэг ч алдагдсан гэж Би хэлнэ. Хүнийг Би хүний арьс нөмөрсөн араатан, хорт могой гэж хардаг, Миний нүдний өмнө хэчнээн өрөвдөлтэй харагдах гэж хичээлээ ч Би түүнд хэзээ ч өршөөнгүй хандахгүй, учир нь хүн хар цагаан, үнэн ба үнэн бишийн ялгааг мэддэггүй. Хүний эрүүл ухаан маш хөшүүн, гэсэн ч тэр ерөөл олж авахыг хүсдэг; хүн чанар нь маш олиггүй атлаа хааны дээд эрхтэй байхыг хүсдэг. Ийм эрүүл ухаантай байж тэр хэний хаан байж чадах юм бэ? Тийм хүн чанартай байж тэр хэрхэн сэнтийд суух юм бэ? Хүн үнэхээр ичгүүргүй! Ихэрхүү зантай өөдгүй амьтан! Ерөөл олж авахыг хүсдэг хүмүүст гэж хэлэхэд, та нар эхлээд толь олоод өөрсдийнхөө муухай дүрийг хар гэж Би зөвлөх байна—хаан болоход хэрэгтэй бүхэн чамд бий юу? Ерөөл хүртэж чадах хүний царай чамд байна уу? Зан чанарт чинь өчүүхэн төдий ч өөрчлөлт гараагүй, ямар ч үнэнийг хэрэгжүүлээгүй

атлаа чи гайхалтай маргаашийг хүсэж л суудаг. Чи өөрийгөө мэхэлж байна! Ийм бохир заваан газарт төрсөн хүнд нийгэм ноцтой муу нөлөө үзүүлж ирсэн, тэрээр бурангуй нийгмийн ёс зүйн нөлөөнд автаж, “дээд боловсролын байгууллага”-д суралцаж ирсэн. Хоцрогдмол үзэл санаа, завхарсан ёс суртахуун, амьдралыг харах тааруухан үзэл, амьдралын жигшүүрт гүн ухаан, ямар ч хэрэггүй оршин тогтнол, амьдралын дорд хэв маяг, зуршил—энэ бүгд нь хүний зүрх сэтгэлийг асар ихээр үймүүлж, мөс чанарыг нь муутгаж, ноцтой доройтуулдаг. Ингэснээр хүн Бурханаас улам бүр холдож, Түүнийг улам их эсэргүүцдэг болсон. Хүний зан чанар өдөр ирэх тусам улам харгис болж, Бурханы төлөө юугаа ч орхиход бэлэн, Бурханыг дуртайяа дуулгавартай дагах, цаашлаад Бурханы илрэлтийг сайн дурааараа эрж хайх хүн ганц ч үгүй болсон. Харин ч хүн Сатаны эзэмшил дор зугаа цэнгэл хөөцөлдөхөөс өөр юу ч хийдэггүй, намаг балчигтай газарт махан биеийн завхралд өөрийгөө тушаадаг. Харанхуйд амьдардаг тэр хүмүүс үнэнийг сонссон хэдий ч хэрэгжүүлье гэж боддоггүй, Бурханы илрэлтийг харсан ч гэсэн Түүнийг эрж хайх сонирхолгүй байдаг. Ингэж их доройтсон хүн төрөлхтөнд аврагдах боломж яаж байх юм бэ? Ингэж их уналтад орсон хүн төрөлхтөн гэрэлд амьдарч яаж чадах юм бэ?

Өөрийн мөн чанарыг мэдэхээс эхлээд үзэл санаа, уг чанар, оюун санааны төлөв гэх үндсэн өөрчлөлтөөр дамжин хүний зан чанар өөрчлөгддөг. Ийм маягаар л хүний зан чанарт жинхэнэ өөрчлөлт гарна. Хүний завхарсан зан чанарын уг шалтгаан нь Сатаны ов мэх, завхрал, хор юм. Хүн Сатанд хүлэгдэж, хянуулсан бөгөөд үзэл санаа, ёс суртахуун, мэдлэг ухаан, эрүүл ухаанд нь Сатан ноцтой хор хүргэсний улмаас зовж зүдэрдэг. Суурь зүйлийг нь Сатан завхруулж, Бурханы анх бүтээсэнтэй огт адилгүй болгосон учраас л хүн Бурханыг эсэргүүцэж, үнэнийг хүлээн авдаггүй. Тиймээс Бурханы талаарх мэдлэг, үнэний талаарх мэдлэгийг нь өөрчлөх үзэл санаа, мэдлэг ухаан, эрүүл ухааны өөрчлөлтөөс нь хүний зан чанарын өөрчлөлт эхлэх ёстой. Хамгийн гүн завхарсан газар нутагт төрсөн хүмүүс Бурхан юу болохыг, Бурханд итгэх гэж юу гэсэн үг болохыг бүр ч мэддэггүй. Хүмүүс хэдий чинээ их завхарсан байна, Бурханы оршин тогтнолыг төдий чинээ мэддэггүй, эрүүл ухаан, мэдлэг ухаанаар төдий чинээ дульхан байдаг. Хүн Бурханд тэрсэлж, эсэргүүцдэг нь Сатан хүнийг завхруулснаас эхтэй. Сатан завхруулсан учраас хүний мөс чанар хөшүүн болсны дээр хүн ёс суртахуунгүй, үзэл бодол нь доройтсон, хоцрогдмол сэтгэлгээтэй байдаг. Сатанд завхруулагдахаасаа өмнө хүн Бурханыг аяндаа дагаж, үгийг нь сонсоод Түүнийг дуулгавартай дагадаг байсан. Тэр угийн эрүүл ухаан, мөс чанар сайтай, хэвийн хүн чанартай байсан. Сатан завхруулсны дараа хүний төрөлх эрүүл ухаан, мөс чанар, хүн чанар үлбэгэр болж, Сатанд эрэмдэглүүлсэн. Тиймээс түүний дуулгавартай байдал болоод Бурханыг гэх хайр нь үгүй болсон. Хүний эрүүл ухаан хэвийн бус болж, зан чанар нь амьтныхтай адил болсон. Бурханд тэрслэх нь улам бүр олширч, ноцтой болсон. Гэсэн ч хүн үүнийгээ мэддэггүй, ухамсарладаг ч үгүй, ердөө л сохроор эсэргүүцэж, тэрсэлж байдаг.

Хүний зан чанар эрүүл ухаан, мэдлэг ухаан, мөс чанараар нь илэрдэг; эрүүл ухаан, мэдлэг ухаан нь эрүүл саруул биш, мөс чанар нь туйлын үлбэгэр болсон учраас хүний зан чанар Бурханы эсрэг тэрсэлдэг. Хүн эрүүл ухаан, мэдлэг ухаанаа өөрчилж чадахгүй бол зан чанараа өөрчилж, бас Бурханы хүсэлд нийцүүлнэ гэж санахын ч хэрэггүй. Ухаан нь эрүүл саруул биш бол хүн Бурханд үйлчилж чадахгүйн дээр Бурханд ашиглуулахад тохирохгүй. “Хэвийн эрүүл ухаан” гэдэг нь Бурханд дуулгавартай, үнэнч байж, Бурханыг хүсэн эрмэлзэж, Бурханы талаар огт эргэлзэхгүй, Бурханыг гэсэн мөс чанартай байхыг хэлдэг. Бурханд нэгэн санаа сэтгэлээр зүтгэж, Бурханыг зориуд эсэргүүцэхгүй байхыг хэлдэг. Хэвийн бус ухаантай хүмүүс ийм байдаггүй. Сатан ялзруулснаас хойш хүн Бурханы талаар үзэлтэй болж, Бурханыг гэсэн хүсэл эрмэлзэл, Түүнд үнэнч байдлаа гээж, Бурханыг гэх мөс чанар гэж бүр юу ч үгүй болсон. Хүн Бурханыг санаатайгаар эсэргүүцэж, шүүмжилдэг, тэр ч бүү хэл ар хударгаар нь Түүн рүү хараал зүхэл урсгадаг. Түүнийг Бурхан гэдгийг хүн сайн мэддэг атлаа ар хударгаар нь Түүнийг шүүмжилж, Бурханыг дуулгавартай дагах ямар ч бодолгүй, ердөө л Түүнээс утга учиргүй юм нэхэж, Түүнд шаардлага тавьдаг. Хэвийн бус ухаантай ийм хүмүүс жигшүүрт зан авираа мэдэж, тэрслүү байдалдаа харамсах чадваргүй юм. Хэрвээ хүмүүс өөрсдийгөө мэдэх чадвартай бол эрүүл ухаан нь бага зэрэг сэргэсэн байна; өөрсдийгөө хараахан мэдэж чадаагүй хүмүүс хэдий чинээ Бурханы эсрэг тэрсэлж байна, төдий чинээ ухаан нь эрүүл саруул бус байдаг.

Хүний завхарсан зан чанарын илрэл нь өөр юунаас ч биш зөвхөн түүний хөшүүн мөс чанар, хорлонт уг чанар, эрүүл саруул бус ухаанаас эхтэй; хэрвээ хүний мөс чанар, эрүүл ухаан нь эргээд хэвийн байдалдаа орж чадвал Бурханы өмнө ашиглуулахад тохирох нэгэн болно. Хүний мөс чанар үргэлж хөшүүн байсаар ирсэн бөгөөд хэзээ ч эрүүл саруул байгаагүй ухаан нь улам мунхаг болж байдаг учраас л хүн Бурханд улам тэрсэлж, тэр ч байтугай Есүсийг загалмайд цовдолж, эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурханыг гэртээ оруулахаас татгалзаж, Бурханы махбодыг яллаж, өчүүхэн дорд гэж үздэг. Хүнд өчүүхэн ч гэсэн хүн чанар байсан бол Бурханы махбод болсон биед тэгж их харгис хандахгүй л байсан; хүн өчүүхэн ч гэсэн эрүүл ухаантай байсан бол бие махбодтой болсон Бурханы биед тэгж их хэрцгий хандахгүй байсан; хүн өчүүхэн ч болов мөс чанартай байсан бол бие махбодтой болсон Бурханд ингэж “талархах”-гүй байсан. Бурхан махбод болсон эрин үед хүн аж төрдөг атлаа өөрт нь тийм сайхан боломж олгосон Бурханд талархаж чадахгүй, харин ч Бурханы ирэлтийг харааж, Бурхан бие махбодтой болсон тухай баримтыг огт тоохгүй, үүнийг эсэргүүцэж, үүнээс залхсан мэт байдаг. Хүн Бурханы ирэлтэд яаж ч ханддаг байсан хамаагүй, Түүнийг өчүүхэн төдий ч таатай угталгүй, Түүнд ухаангүй шаардлага тавьсаар ирсэн ч, товчхондоо Бурхан ажлаа үргэлж тэвчээртэй үргэлжлүүлж ирсэн. Хүний зан чанар туйлын хэрцгий болж, эрүүл ухаан нь дээд зэргээр дүйнгэ болж, мөс чанар нь ёрын муу нэгэнд бүрмөсөн дэвслүүлээд хүний анхдагч мөс чанар байхаа аль эрт больсон. Хүн

төрөлхтөнд маш их амь, нигүүлслийг хайрласных нь төлөө бие махбодтой болсон Бурханд хүн талархдаггүйгээр үл барам, өөрт нь үнэнийг өглөө гэж Бурханд дургүйцэх болсон; хүн үнэнийг өчүүхэн төдий ч сонирхдоггүй учраас л Бурханд дургүйцэх болсон. Хүн бие махбодтой болсон Бурханы төлөө амиа золиосолж чаддаггүйгээр үл барам, Бурханаас тус гуйхыг хичээж, өгсөн зүйлээсээ хэдэн арав дахин их хүү нэхдэг. Иймэрхүү мөс чанар, эрүүл ухаантай хүмүүс үүнийг том асуудал биш гэж үздэг бөгөөд Бурханы төлөө маш ихийг зарлагадсан байхад Бурхан өөрсдөд нь хэтэрхий багыг өгсөн гэж итгэсээр байдаг. Надад аяга ус өгчхөөд алгаа тосон хоёр аяга сүүний мөнгө төл гэж нэхдэг, эсвэл нэг шөнө хонох өрөө өгчхөөд хэдэн шөнийн төлбөр нэхдэг хүмүүс бий. Ийм хүн чанар, ийм мөс чанартайгаар та нар амь олж авахыг хүссэн хэвээр байж яаж чадна вэ? Та нар ямар жигшмээр өөдгүй амьтад вэ! Хүний хүн чанар, мөс чанар ийм байдаг учраас бие махбодтой болсон Бурхан газар сайгүй хэрэн хэсэж, хоргодох газаргүй яваа билээ. Үнэхээр мөс чанар, хүн чанартай хүмүүс, бие махбодтой болсон Бурхан ийм их ажил хийх нь байтугай, ямар ч ажил хийгээгүй байсан ч шүтэн мөргөж, бүх сэтгэл зүрхээрээ Түүнд үйлчлэх ёстой. Энэ бол эрүүл саруул ухаантай хүмүүсийн хийх ёстой зүйл, энэ бол хүний үүрэг билээ. Ихэнх хүн Бурханд үйлчлэхдээ бүр болзол ярьдаг: Бурхан байна уу, хүн байна уу гэдэг нь тэдэнд хамаагүй, болзлынхоо талаар л ярьж, хүслээ хангах гэж л чармайдаг. Та нар Надад хоол хийж өгөхдөө үйлчилгээний хөлс нэхдэг, Миний төлөө гүйхдээ гүйсний төлбөрөө нэхдэг, Миний төлөө ажиллахдаа ажлын хөлсөө шаарддаг, Миний хувцсыг угаахдаа угаалгын төлбөр шаарддаг, чуулганыг хангахдаа биеэ тэнхрүүлэх зардлыг нэхдэг, үг хэлэхдээ илтгэгчийн төлбөр шаарддаг, ном тараахдаа түгээлтийн зардал шаарддаг, бичихдээ бичсэний төлбөрөө нэхдэг. Миний харьцаж байсан хүмүүс Надаас нөхөн төлбөр хүртэл нэхдэг бол гэр лүү нь буцаасан хүмүүс нэр хүндэд нь хохирол учруулсны төлбөр шаарддаг; гэрлээгүй хүмүүс инж юм уу алдсан залуу насныхаа нөхөн төлбөрийг нэхдэг; тахиа нядалдаг хүмүүс нядалгааны хөлс нэхдэг, хоол шардаг хүмүүс шарсныхаа төлбөрийг нэхдэг, шөл хийдэг хүмүүс төлбөрийг нь бас л нэхдэг… Эдгээр нь та нарын өндөр дээд, агуу хүн чанар, та нарын халуун дулаан мөс чанараас гарсан үйлдлүүд. Та нарын эрүүл ухаан хаана байна? Та нарын хүн чанар хаана байна? Би та нарт хэлчихье! Энэ хэвээрээ байвал Би та нарын дунд ажиллахаа болино. Би хүний арьс нөмөрсөн араатны сүрэг дунд ажиллахгүй, зэрлэг догшин зүрх сэтгэлээ эелдэг царайгаар нуудаг тийм бүлэг хүний төлөө Би ингэж зовохгүй, аврагдах өчүүхэн төдий ч боломжгүй тийм сүрэг амьтны төлөө Би тэсэж тэвчихгүй. Би та нараас нүүр буруулах өдөр та нарын үхэх өдөр, та нарыг харанхуй нөмрөх өдөр, та нарыг гэрэл орхих өдөр билээ. Би та нарт хэлчихье! Амьтнаас ч долоон дор та нар шиг хүмүүст Би хэзээ ч өгөөмөр хандахгүй! Миний үг, үйлдэлд хэмжээ хязгаар бий, та нарын хүн чанар, мөс чанар энэ чигээрээ байвал Би өөр ямар ч ажил хийхгүй, учир нь та нарын мөс чанар хэтэрхий дутуу дулимаг, та нар Надад маш их зовлон шаналал учруулсан, жигшмээр зан авир чинь

Намайг маш их зэвүүцүүлдэг! Хүн чанар, мөс чанарааараа маш дутуу дулимаг хүмүүст аврагдах боломж хэзээ ч байхгүй; тийм цэвдэг сэтгэлтэй, талархаж мэддэггүй хүмүүсийг Би хэзээ ч аврахгүй. Миний өдөр ирэхэд догшин уур хилэнг минь нэгэнтээ хүргэсэн дуулгаваргүй хүүхдүүд дээр Би шатам халуун галаа мөнхөд асгах болно. Над руу доромж үг чулуудаж, Намайг хаясан тэр амьтдад мөнхийн шийтгэлээ ноогдуулна. Нэгэнтээ Надтай хамт хооллож, аж төрж байсан атлаа Надад итгэдэггүй, Намайг доромжилж, Надаас урвасан дуулгаваргүй хөвгүүдийг уур хилэнгийн галаараа үүрд шатаах болно. Миний уур хилэнг хүргэсэн бүх хүнийг Би шийтгэнэ, нэгэнтээ Миний хажууд Надтай эн тэнцүү зогсохыг хүссэн хэр нь Надад шүтэн мөргөж, Намайг дуулгавартай дагаагүй тэр араатнууд дээр Би уур хилэнгээ тэр чигт нь буулгана; нэг үе Миний хэлсэн нуцад баясаж, Миний халамжийг эдэлж байсан, Надаас материаллаг таашаал булаах гэж оролдсон тэр амьтад дээр хүнийг цохидог саваа минь бууна. Миний байр суурийг эзлэхийг оролдсон хэнийг ч Би уучлахгүй; Надаас хоол хүнс, хувцас хунар булаахаар оролддог хүмүүсээс хэнийг нь ч Би өршөөхгүй. Одоохондоо та нар амар тайван байж, Надаас хэтэрсэн зүйл шаардсаар л байна. Уур хилэнгийн өдөр ирэхэд та нар Надаас дахиж юу ч шаардахгүй; тэр үед Би та нарыг шавайгаа ханатал “баясгана”, Би та нарыг нүүрээр чинь газар хатгуулна, тэгээд та нар дахин хэзээ ч босож ирж чадахгүй! Эрт орой хэзээ нэгэн цагт, Би энэ өрөө та нарт “төлөх” болно—та нар энэ өдөр ирэхийг тэвчээртэйгээр хүлээнэ гэж Би найдаж байна.

Жигшмээр энэ хүмүүс хэрээс хэтэрсэн хүслээ үнэхээр хойш тавиад Бурхан руу эргэн очиж чадвал аврагдах боломж одоо ч бий; Бурханыг үнэхээр хүсэн эрмэлздэг зүрх сэтгэлтэй бол Бурхан тэр хүнийг орхихгүй. Хүн Бурханыг олж авахдаа бүтэлгүйтдэг нь Бурхан сэтгэл хөдлөлтэй юм уу хүнээр авхуулахыг хүсдэггүйдээ биш, харин хүн Бурханыг олж авах гэж хүсдэггүй, Бурханыг яаралтай эрж хайдаггүйгээс болдог. Бурханыг үнэхээр эрж хайдаг хүнийг Бурхан юу гэж хараах юм бэ? Эрүүл саруул ухаантай, мэдрэмжтэй мөс чанартай хүнийг Бурхан юу гэж хараах юм бэ? Бурханд үнэхээр шүтэн мөргөж, үйлчилдэг хүнийг Түүний уур хилэнгийн гал юу гэж шатаах юм бэ? Бурханыг дуртайяа дуулгавартай дагадаг хүн Бурханы гэрээс юу гэж хөөгдөх юм бэ? Бурханыг хайрлаад хайрлаад ханадаггүй хүн юу гэж Бурханы шийтгэлд амьдрах юм бэ? Бурханы төлөө бүхнийг дуртайяа орхидог хүн юу гэж хоосон хоцрох юм бэ? Хүн Бурханыг эрэлхийлэх дургүй, өөрийн өмч хогшлыг Бурханы төлөө зарцуулах дургүй, нэг насны амьдралынхаа хичээл зүтгэлийг Бурханд зориулах дургүй байдаг; харин ч Бурхан хэтэрхий даварч байна, Бурханы хэтэрхий олон зүйл нь хүний үзэлтэй зөрчилдөж байна гэж хэлдэг. Иймэрхүү хүн чанартай бол хичээл зүтгэлээ харамгүй гаргалаа ч Бурханы сайшаалыг та нар хүртэж бас л чадахгүй, Бурханыг эрж хайдаггүйг чинь хэлэхийн ч хэрэггүй. Та нар бол хүн төрөлхтний гологдол бараа гэдгээ мэдэхгүй юу? Та нарынхаас дор хүн чанар байхгүй гэдгийг мэдэхгүй юу? Бусад хүн та нарыг “хүндлэхдээ” юу гэж дууддагийг мэдэхгүй гэж үү? Бурханыг үнэхээр хайрладаг

хүмүүс та нарыг эцэг чоно, эх чоно, хүү чоно, ач чоно гэж нэрлэдэг; та нар бол чонын үр удам, чонын угсаатан, та нар ялгамж чанараа мэдэж аваад, үүнийгээ хэзээ ч мартах ёсгүй. Өөрийгөө алдартай хүн гэж бүү бод: Та нар бол хүн төрөлхтөн дотроос хамгийн хэрцгий, хүн-бус бүлэг юм. Та нар эдгээрийн алийг нь ч мэдэхгүй юу? Дунд чинь ажилласнаараа Би хэр их эрсдэл үүрснийг та нар мэдэх үү? Та нарын эрүүл ухаан эргээд хэвийн болохгүй бол, мөс чанар чинь хэвийн ажиллаж чадахгүй бол, та нар “чоно” нэршлээсээ хэзээ ч ангижирч чадахгүй, хараалын өдрөөс хэзээ ч зугтаж чадахгүй, шийтгэлийнхээ өдрөөс хэзээ ч мултарч чадахгүй. Та нар ямар ч үнэ цэнгүй дорд амьтан болж төрсөн. Та нар бол угаасаа өлсгөлөн чонын сүрэг, овоорсон хог хаягдал бөгөөд та нараас ялгаатай нь Би тус гуйх гэсэндээ бус, харин ажлын хэрэгцээ шаардлагын улмаас та нар дээр ажилладаг. Та нар энэ маягаараа тэрслүү хэвээр байвал Би Өөрийн ажлыг зогсоож, та нар дээр дахин хэзээ ч ажиллахгүй; харин ч Би сэтгэлдээ нийцсэн өөр бүлэг рүү ажлаа шилжүүлж, та нарыг ийнхүү үүрд орхих болно, учир нь Надад дайсагнадаг хүмүүсийг Би харахыг хүсдэггүй. Тэгэхээр та нар Надтай нийцтэй баймаар байна уу эсвэл Надад дайсагнамаар байна уу?

БУРХАНЫГ МЭДДЭГГҮЙ БҮХ ХҮН БОЛ БУРХАНЫГ ЭСЭРГҮҮЦДЭГ ХҮМҮҮС ЮМ

Бурханы ажлын зорилго, хүн дээр хүрдэг үр нөлөө болон хүний төлөөх Бурханы хүсэл яг юу болохыг ухаарах нь Бурханыг дагадаг хүн бүрийн хүрэх ёстой зүйл юм. Өнөө үед бүх хүнд дутагддаг зүйл бол Бурханы ажлын тухай мэдлэг билээ. Дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш өнөөг хүртэл хүмүүс дээр ажилласан Бурханы үйл хэрэг, Бурханы бүхий л ажил болон хүнийг гэх Бурханы хүсэл яг юу болох—эдгээр нь хүний мэддэг ч үгүй, ойлгодог ч үгүй зүйлс юм. Энэхүү дутагдал зөвхөн шашны ертөнц даяар харагдаад зогсохгүй, бас Бурханд итгэдэг бүх хүнээс ч харагддаг. Чи үнэхээр Бурханыг харж, Бурханы мэргэн ухааныг үнэхээр ухаарч, Бурханы хийсэн бүх үйл хэргийг харж, Бурханд юу байгаа, Тэр юу болохыг таньж—Түүний элбэг дэлбэг байдал, мэргэн ухаан, гайхамшиг болон хүмүүст хийсэн бүх ажлыг нь харах өдөр ирэхэд—тэр үед чи Бурханд итгэх итгэлдээ амжилт гаргасан байх болно. Бурхан бүхнийг хамардаг ба бүхэлдээ элбэг дэлбэг гэж хэлэх үед чухамдаа Тэр ямар байдлаар бүхнийг хамардаг вэ, мөн ямархуу маягаар бүхэлдээ элбэг дэлбэг байдаг вэ? Хэрвээ чи үүнийг ойлгохгүй бол чамайг Бурханд итгэдэг гэж үзэж болохгүй. Шашны ертөнц дэх хүмүүс Бурханд итгэгчид бус, харин мууг үйлдэгч, диаволын төрлийнх гэж Би яагаад хэлдэг вэ? Тэд бол мууг үйлдэгчид гэж хэлж байгаа минь тэд Бурханы хүслийг ойлгодоггүй, мэргэн ухааныг нь хардаггүйгээс болж байгаа юм. Бурхан Өөрийн ажлыг хэзээ ч тэдэнд илчилдэггүй. Тэд бол сохор; тэд Бурханы үйл хэргийг харж чаддаггүй, Бурханд хаягдсан ба тэдэнд Бурханы

халамж, хамгаалалт огтхон ч байдаггүй, Ариун Сүнсний ажил бүр ч байдаггүй. Бурханы ажилгүй хүмүүс бол бүгд мууг үйлдэгчид, Бурханыг эсэргүүцэгчид юм. Миний ярьдаг, Бурханыг эсэргүүцэгчид нь Бурханыг мэддэггүй хүмүүс, Бурханыг амаараа хүлээн зөвшөөрдөг атлаа Түүнийг мэддэггүй хүмүүс, Бурханыг дагадаг атлаа Түүнд дуулгавартай байдаггүй хүмүүс, Бурханы нигүүлслийг эдэлдэг атлаа Түүний гэрчлэлд зогсож чаддаггүй хүмүүсийг хэлдэг. Бурханы ажлын зорилгыг ойлгохгүйгээр, хүнд Бурханы хийдэг ажлыг ойлгохгүйгээр хүн Бурханы хүсэлтэй нийцэж чадахгүй, Бурханы гэрчлэлд зогсож ч чадахгүй. Хүн Бурханыг эсэргүүцдэгийн шалтгаан нь нэг талаар хүний завхарсан зан чанараас, нөгөө талаар Бурханыг мэддэггүйгээс болон Бурханы ажилладаг зарчим, хүнийг гэх Түүний хүслийг ойлгодоггүйгээс болдог. Энэ хоёр тал нь хамтдаа Бурханд хандах хүний эсэргүүцлийн түүхийг бүрдүүлдэг. Хүний уг чанар дотор Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл байдаг учраас шинэхэн итгэгчид Бурханыг эсэргүүцдэг байхад олон жил итгэсэн хүмүүс завхарсан зан чанар дээрээ нэмээд Бурханыг мэддэггүйгээсээ болж Түүнийг эсэргүүцдэг. Бурханыг махбод болохоос өмнөх хугацаанд, хүн тэнгэр дэх Бурханы тогтоосон зарлигуудыг мөрддөг эсэхэд үндэслэн Бурханыг эсэргүүцдэг эсэх нь хэмжигддэг байв. Тухайлбал, Хуулийн эрин үед Еховагийн хуулийг мөрддөггүй хэнийг ч бай Бурханыг эсэргүүцдэг хүн гэж үздэг байлаа; Еховагийн тахилыг хулгайлсан хэнийг ч, Еховагийн тааллыг олсон хүмүүсийг эсэргүүцдэг хэнийг ч Бурханыг эсэргүүцдэг хүн гэж үзээд чулуугаар шидэж хөнөөдөг байв; эцэг, эхээ хүндэлдэггүй хэнийг ч, мөн бусдыг цохисон юм уу хараасан хэнийг ч хуулийг мөрдөөгүй хүн гэж үздэг байлаа. Еховагийн хуулийг мөрдөөгүй бүх хүнийг Түүнийг эсэргүүцэж байна гэж үздэг байсан юм. Нигүүлслийн эрин үед ийм байхаа больж, Есүсийг эсэргүүцдэг хэнийг ч Бурханыг эсэргүүцсэн хүн гэж үзээд, Есүсийн айлдсан үгийг дуулгавартай дагаагүй хэнийг ч Бурханыг эсэргүүцсэн нэгэн гэж үзсэн билээ. Энэ удаа, Бурханыг эсэргүүцдэг арга замыг илүү үнэн зөв, илүү бодитоор тодорхойлсон. Бурханыг хараахан махбод болоогүй байх үед хүн Бурханыг эсэргүүцдэг эсэх нь тэнгэр дэх үл үзэгдэх Бурханд шүтэн мөргөж, Түүнийг хүндэлдэг эсэхэд нь үндэслэн хэмжигддэг байлаа. Тухайн үед Бурханыг эсэргүүцэх арга замыг төдийлөн бодитой тодорхойлоогүй, учир нь тэр үед хүн Бурханыг харж чадаагүй, Бурханы дүр ямархуу болохыг ч, Тэр хэрхэн ажиллаж, ярьдгийг ч мэдээгүй байсан юм. Бурхан хүнд хараахан харагдаагүй байсан учраас хүнд Бурханы талаар ямар ч үзэл байгаагүй ба тодорхойгүй байдлаар Бурханд итгэж байлаа. Тиймээс, хүн төсөөлөлдөө Бурханд яаж ч итгэж байсан бай, Бурхан хүнийг яллаагүй, хүнд хэтэрхий их шаардлага ч тавиагүй, учир нь хүн Бурханыг огтхон ч харж чадахгүй байв. Бурханыг махбод болж, хүмүүсийн дунд ажиллахаар ирэх үед бүгд Бурханыг харж, үгийг нь сонсож, махбодоороо Бурханы хийдэг бүх үйл хэргийг хардаг. Тэр үед хүний бүх үзэл хөөс болдог. Бурхан махбодоор гарч ирэхийг харсан хүмүүсийн хувьд, хэрвээ тэд Түүнийг дуртайяа дуулгавартай дагадаг бол яллагдахгүй, харин зориуд Түүний эсрэг зогсдог хүмүүсийг Бурханыг эсэргүүцэгч

гэж үзэх болно. Тийм хүмүүс бол антихристүүд, Бурханыг зориуд эсэргүүцдэг дайснууд юм. Бурханы талаар үзэл өвөрлөдөг боловч Түүнийг дуулгавартай дагахад бэлэн, дуулгавартай дагахыг хүсдэг хүмүүс яллагдахгүй. Бурхан бодол, санаанд нь үндэслэж бус, харин санаа зорилго, үйлдэлд нь үндэслэн хүнийг ялладаг. Хэрвээ хүнийг бодол, санааных нь үндсэн дээр ялладаг байсан бол Бурханы хилэнт гараас зугтаж чадах ганц ч хүн үгүй. Бие махбодтой болсон Бурханыг санаатайгаар эсэргүүцдэг хүмүүс дуулгаваргүй байдлынхаа улмаас шийтгүүлнэ. Бурханыг зориуд эсэргүүцдэг энэ хүмүүсийн тухайд бол, тэдний эсэргүүцэл Бурханы талаарх үзлээс нь үүдэн гардаг ба энэ нь Бурханы ажлыг үймүүлэх үйлдэл хийхэд хүргэдэг. Энэ хүмүүс Бурханы ажлыг зориуд эсэргүүцэж, сүйрүүлдэг. Тэд Бурханы талаар үзэлтэй байгаад зогсохгүй Түүний ажлыг үймүүлэх зүйлсийг хийдэг, энэ шалтгааны улмаас ийм төрлийн хүмүүс яллагдана. Бурханы ажлыг дур зоргоороо үймүүлдэггүй хүмүүсийг нүгэлтнүүд хэмээн яллахгүй, учир нь тэд дуртайяа дуулгавартай дагаж чаддаг бөгөөд үймээн, саад тотгор учруулах үйлдэл хийдэггүй. Ийм хүмүүс яллагдахгүй. Гэхдээ хүмүүс Бурханы ажлыг олон жилийн турш туулсан ч Бурханы талаар үзэл өвөрлөсөөр, бие махбодтой болсон Бурханы ажлыг мэдэх чадваргүй хэвээр байж, хэчнээн олон жил Түүний ажлыг туулсан ч Бурханы талаар үзэл тээсээр, Бурханыг мэдэж авч чадахгүй хэвээр байвал үймүүлэх юм хийгээгүй ч гэсэн тэдний зүрх сэтгэл Бурханы талаарх олон үзлээр дүүрсэн байх ба эдгээр үзэл ил болоогүй ч гэсэн, тийм хүмүүс Бурханы ажилд ямар ч тус дэмгүй байдаг. Тэд Бурханы төлөө сайн мэдээ түгээж, эсвэл Түүний төлөө гэрчлэлд зогсож чадахгүй. Ийм хүмүүс бол ямар ч хэрэггүй, тэнэгүүд билээ. Тэд Бурханыг мэддэггүй, түүнчлэн Бурханы талаарх үзлээ хаяж огт чаддаггүй учраас яллагддаг. Үүнийг ингэж хэлж болно: Шинэхэн итгэсэн хүмүүсийн хувьд Бурханы талаар үзэл тээх юм уу Түүний талаар юу ч мэдэхгүй байх нь хэвийн юм, харин Бурханд олон жил итгэж, Бурханы ихээхэн ажлыг туулсан хүн үзэл өвөрлөсөөр байх нь хэвийн бус бөгөөд Бурханы талаар ямар ч мэдлэггүй байх нь бүр ч хэвийн бус юм. Энэ нь хэвийн бус байдал учраас тэд яллагддаг. Энэ хэвийн бус хүмүүс бүгд хог новш; тэд бол Бурханыг хамгийн их эсэргүүцдэг хүмүүс бөгөөд Бурханы нигүүлслийг хий дэмий эдэлсэн хүмүүс юм. Ийм хүмүүс эцэстээ бүгд таягдан хаягдана!

Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс бөгөөд Бурханы ажлын зорилгыг ойлгож авсан атлаа Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар эрж хайдаггүй хүмүүс бол Бурханыг бүр ч их эсэргүүцдэг хүмүүс юм. Том сүмд Библи уншиж, үүнийг бүхэл өдөржингөө цээжээр уншдаг хүмүүс байдаг атал тэдний дундаас нэг нь ч Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй. Тэдний дундаас нэг нь ч Бурханыг мэдэж чаддаггүй; тэдний дундаас бүр нэг ч хүн Бурханы хүсэлд нийцэж чаддаггүй. Тэд бүгдээрээ үнэ цэнгүй, өөдгүй хүмүүс бөгөөд Бурханд зааж сургахын тулд дор бүрнээ өндөрт зогсдог. Тэд Бурханы далбааг намируулдаг атлаа Түүнийг зориуд эсэргүүцдэг. Бурханд итгэдэг гэх атлаа тэд хүний махыг

идэж, цусыг уусаар байдаг. Ийм хүмүүс бүгд хүний сүнсийг залгидаг диаволууд, зөв замд орохоор хичээж буй хүмүүст зориуд саад учруулдаг толгойлогч чөтгөрүүд, мөн Бурханыг эрж хайдаг хүмүүст садаа болдог бул хар чулуу билээ. Тэд “эрүүл чийрэг бие махбодтой” харагдаж болох ч Бурханыг эсэргүүцэхэд бусдыг хөтөлдөг антихристүүд гэдгийг антихристүүд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Хүний сүнсийг залгидаг амьд диаволууд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Бурханы өмнө өөрсдийгөө өндрөөр үнэлдэг хүмүүс бол хамгийн дорд хүмүүс, харин өөрсдийгөө дорд гэж боддог хүмүүс бол хамгийн эрхэм юм. Бурханы ажлыг мэддэг гэж боддог, түүнчлэн Бурханыг шууд харж байхдаа ч Түүний ажлыг асар чангаар бусдад тунхагладаг хүмүүс бол хамгийн мэдлэггүй хүмүүс юм. Ийм хүмүүс бол Бурханы гэрчлэлгүй хүмүүс, биеэ тоосон, ихэрхүү хүмүүс билээ. Бодит туршлагатай, Бурханы талаар бодитой мэдлэгтэй атлаа өөрсдийгөө Бурханы талаар дэндүү бага мэдлэгтэй гэж боддог хүмүүсийг Тэр хамгийн их хайрладаг. Ийм хүмүүс л үнэхээр гэрчлэлтэй байдаг ба Бурханаар төгс болгуулж үнэхээр чаддаг. Бурханы хүслийг ойлгодоггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханы хүслийг ойлгодог атлаа үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханы үгийг идэж, уудаг атлаа Бурханы үгийн мөн чанарын эсрэг явдаг хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; бие махбодтой болсон Бурханы талаар үзэл тээдэг, түүнчлэн тэрслүү санаа зорилготой хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханыг шүүдэг хүмүүс бол Бурханыг эсэргүүцэгчид; Бурханыг мэдэж, эсвэл Түүнд гэрчлэл хийж чаддаггүй хэн боловч Бурханыг эсэргүүцэгчид билээ. Иймээс Би та нарыг шавдуулж байна: Хэрвээ та нарт энэ замаар алхах итгэл үнэхээр байгаа бол үргэлжлүүлэн дага. Харин та нар Бурханыг эсэргүүцэхгүй байж чадахгүй бол хэтэрхий оройтохоосоо өмнө явсан чинь дээр. Тэгэхгүй бол, та нарын хувьд юмс муугаар эргэх магадлал туйлын өндөр, учир нь та нарын уг чанар үнэхээр дэндүү их завхарсан. Та нарт үнэнч сэтгэл, дуулгавартай байдал, зөвт байдал, үнэнээр цангасан зүрх сэтгэл, Бурханыг гэх хайр өчүүхэн төдий ч байхгүй. Бурханы өмнөх нөхцөл байдал чинь туйлын замбараагүй байдаг гэж хэлж болно. Та нар баримтлах учиртай зүйлээ баримталдаггүй, ярих учиртай зүйлээ ярьж чаддаггүй. Мөн хэрэгжүүлэх учиртай зүйлээ хэрэгжүүлж чадаагүй, биелүүлэх учиртай чиг үүргээ биелүүлж чадаагүй. Та нарт байх учиртай үнэнч зан, мөс чанар, дуулгавартай байдал юм уу шийдвэр байдаггүй. Туулах ёстой зовлонгоо туулаагүй, та нарт байх учиртай итгэл ч байхгүй. Нэлээд энгийнээр хэлбэл, та нар ямар ч үнэ цэнгүй: Үргэлжлүүлэн амьдрахаас ичихгүй байна гэж үү? Та нар мөнхөд амрахаар нүдээ аньж, тэгснээрээ та нарын тусын тулд санаа зовж, та нарын төлөө зовлон туулахаас Бурханыг хэлтрүүлсэн нь дээр гэж Би ятгаж байна. Та нар Бурханд итгэдэг ч Түүний хүслийг мэддэггүй; Бурханы үгийг идэж, уудаг ч хүнээс Бурханы шаарддаг зүйлийг биелүүлж чаддаггүй. Бурханд итгэдэг ч Түүнийг мэддэггүй бөгөөд ямар ч зорьсон зорилгогүй, ямар ч үнэ цэнгүй, ямар ч утга учиргүй амьдардаг. Та нар хүний хувиар амьдардаг ч ямар ч мөс чанар, ёс жудаг, өчүүхэн төдий ч найдвартай байдал байдаггүй—та

нар өөрсдийгөө хүн гэж нэрлэж чадна гэж үү? Та нар Бурханд итгэдэг атлаа Түүнийг мэхэлдэг; түүнээс гадна, Бурханы мөнгийг аваад, Түүнд өргөсөн тахилыг иддэг. Гэсэн ч эцэст нь Бурханы мэдрэмжийг өчүүхэн төдий ч хайхардаггүй, Бурханыг гэх жаахан ч болов мөс чанар харуулдаггүй. Та нар Бурханы хамгийн ялихгүй шаардлагыг ч биелүүлж чаддаггүй. Та нар өөрсдийгөө хүн гэж нэрлэж чадна гэж үү? Бурханы хангасан хоолыг идэж, Түүний өгсөн хүчилтөрөгчөөр амьсгалж, нигүүлслийг нь эдэлдэг ч эцэст нь та нар Бурханы талаар өчүүхэн төдий ч мэддэггүй. Харин ч та нар Бурханыг эсэргүүцдэг ямар ч хэрэггүй хүмүүс болсон. Тэгэхээр та нар нохойноос ч дор араатан бус уу? Амьтдын дунд та нараас илүү хорлонтой амьтан байгаа гэж үү?

Өндөр индэр дээр зогсоод бусдад зааж сургадаг тэдгээр пастор, ахлагч бол Бурханыг эсэргүүцэгчид бөгөөд Сатаны хамсаатан юм; өндөр индэр дээр зогсоод бусдад зааж сургадаггүй та нар Бурханыг бүр ч их эсэргүүцдэг бус уу? Та нар бүр тэднээс ч илүү Сатантай сүлбэлддэг бус уу? Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй хүмүүс Бурханы хүсэлд хэрхэн нийцэхээ мэддэггүй. Мэдээж, Бурханы ажлын зорилгыг ойлгодог хүмүүс Бурханы хүсэлд хэрхэн нийцэхээ мэдэхгүй байна гэж үгүй. Бурханы ажил хэзээ ч алдаа мадаггүй байдаг; харин ч хүний эрэл хайгуул л дутагдалтай. Бурханыг дур зоргоороо эсэргүүцдэг өөдгүй хүмүүс тэр пастор, ахлагч нараас ч илүү зэвүүн, хорлонтой бус уу? Бурханыг эсэргүүцдэг хүн маш олон байдаг ч тэдний дунд Бурханыг эсэргүүцдэг олон өөр арга зам байдаг. Төрөл бүрийн итгэгчид байдгийн адилаар Бурханыг эсэргүүцдэг, өөр хоорондоо адилгүй янз бүрийн хүмүүс бий. Бурханы ажлын зорилгыг тодорхой танин мэдэж чаддаггүй хүмүүсийн нэг нь ч аврагдаж чадахгүй. Хүн урьд нь Бурханыг хэрхэн эсэргүүцэж байснаас үл хамааран, Бурханы ажлын зорилгыг ойлгож авч, Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд хичээл чармайлтаа зориулах үед түүний урьдын бүх нүглийг Бурхан арилгах болно. Хүн үнэнийг эрж хайж, үнэнийг хэрэгжүүлж байгаа цагт хийсэн зүйлийг нь Бурхан санахгүй. Түүнчлэн, үнэнийг хэрэгжүүлснийх нь үндсэн дээр Бурхан хүнийг зөвтгөдөг. Энэ нь Бурханы зөвт байдал юм. Хүн Бурханыг харж, Түүний ажлыг туулахаасаа өмнө Бурханд хэрхэн хандаж байсан нь хамаагүй, Тэр үүнийг санадаггүй. Харин Бурханыг харж, Түүний ажлыг туулмагц хүний бүх үйлдэл, үйл хэргийг Бурхан “түүхэн бичигт” бичнэ, учир нь хүн Бурханыг харж, Түүний ажил дотор амьдарсан билээ.

Хүн Бурханд юу байгаа болон Тэр юу болохыг үнэхээр харж, дээдийн дээд байдлыг нь харж, Бурханы ажлыг үнэхээр мэдэж авах үед, түүнчлэн хүний хуучин зан чанар өөрчлөгдөх үед Бурханыг эсэргүүцдэг тэрслүү зан чанараа бүрэн хаясан байх болно. Нэгэн цагт хүн бүр Бурханыг эсэргүүцсэн ба нэгэн цагт хүн бүр Бурханы эсрэг тэрсэлсэн гэж хэлж болно. Гэвч хэрвээ чи бие махбодтой болсон Бурханыг дуртайяа дуулгавартай дагаж, энэ үеэс эхлэн үнэнч байдлаараа Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгаж, хэрэгжүүлэх учиртай үнэнийг хэрэгжүүлж, биелүүлэх учиртай үүргээ биелүүлж, мөрдөх учиртай дэг журмыг мөрддөг бол чи

Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд тэрслүү байдлаа хаяхыг хүсдэг, Бурханаар төгс болгуулж чадах хүн юм. Чи алдаагаа харахаас татгалзаж, гэмших санаагүй байвал, мөн Бурхантай хамтран ажиллаж, Бурханыг сэтгэл хангалуун байлгах өчүүхэн ч болов санаа зорилгогүйгээр тэрслүү үйлдлээ хэвээр үргэлжлүүлж байвал чам шиг ийм зөрүүд, тэнэг хүн гарцаагүй шийтгүүлэх ба Бурханаар төгс болгуулах нэгэн байж хэзээ ч чадахгүй. Тийм болохоор чи өнөөдөр Бурханы дайсан, маргааш ч бас Бурханы дайсан байх бөгөөд цаашид ч Бурханы дайсан хэвээр үлдэх болно; чи үүрд Бурханыг эсэргүүцэгч, Бурханы дайсан байх болно. Тэгвэл Бурхан чамайг яаж хэлтрүүлж чадах юм бэ? Бурханыг эсэргүүцэх нь хүний уг чанар боловч уг чанараа өөрчлөх нь дааж давшгүй байдгаас болоод хүн Бурханыг эсэргүүцэх “нууцыг” зориуд эрж хайх ёсгүй. Хэрвээ тийм бол хэтэрхий оройтохоосоо өмнө явсан чинь дээр, ирээдүйд гэсгээлт чинь илүү хатуу ширүүн болох вий, мөн зэрлэг догшин уг чанар чинь гарч ирж, махан бие чинь эцэстээ Бурханаар устгуулахдаа тултал дийлдэшгүй болох вий. Чи ерөөл хүртэхийн тулд Бурханд итгэдэг; гэвч эцэст нь золгүй явдал л чамд тохиолдох юм бол ичгүүртэй байх бус уу? Өөр төлөвлөгөө зохиосон нь хамаагүй дээр гэж Би та нарыг шавдуулж байна. Өөр юу ч хийсэн бай, Бурханд итгэхээс дээр байх болно: Мэдээж ганцхан энэ зам л байдаг байж таарахгүй. Та нар үнэнийг эрж хайгаагүй бол үргэлжлүүлэн амьдрах байсан биз дээ? Яах гэж ийм маягаар Бурхантай зөрөлдөх ёстой гэж?

ЧУУЛГАНУУДААР ЯВАХДАА ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ

II

(1992 ОНЫ 11-Р САР—1993 ОНЫ 6-Р САР)

АЖИЛ БА ОРОЛТ 1

Хүмүүс Бурханд итгэх зөв замаар алхаж эхэлсэн цагаас хойш олон зүйл тэдний хувьд ойлгомжгүй хэвээр үлдсэн. Тэд Бурханы ажлын талаар болон өөрсдийн хийх ёстой ихээхэн ажлын тухайд бүрэн самуурч будилсаар байдаг. Нэг талаар энэ нь, тэдний туршлага дахь гажуудал болон тэдний хүлээн авах чадварын хязгаараас болдог; нөгөө талаар, Бурханы ажил хүмүүсийг хараахан энэ үе шатанд хүргээгүйгээс болдог. Иймээс хүн бүрийн хувьд ихэнх сүнслэг асуудал тодорхойгүй байдаг. Та нар юунд орох ёстойгоо тодорхой мэддэггүйгээр үл барам, Бурханы ажлын талаар бүр ч мэддэггүй. Энэ нь та нарын дотор оршдог дутагдалтай асуудал төдийхөн биш: Харин шашны ертөнц дэх бүх хүнд нийтлэг байдаг асар том өө сэв юм. Хүмүүс яагаад Бурханыг мэддэггүйн гол түлхүүр энд оршдог тул энэхүү өө сэв нь Түүнийг эрж хайдаг бүх хүний нийтлэг дутагдал билээ. Хэн ч, хэзээ ч Бурханыг мэдээгүй, хэзээ ч Түүний үнэн царайг хараагүй. Үүнээс болоод Бурханы ажил, уулыг хөдөлгөж, тэнгис далайг ширгээх мэт хэцүү бэрх болдог. Маш олон хүн Бурханы ажлын төлөө амиа золиосолсон; маш олон хүн Түүний ажлаас үүдэн хаягдсан; Түүний ажлын төлөө маш олон хүн үхтлээ тарчилсан; маш олон хүний нүд Бурханыг гэх хайрын нулимсаар дүүрч, хилсээр нас барсан; маш олон хүн харгис хэрцгий, зэрлэг балмад хавчлагатай тулгарсан… Энэ бүх эмгэнэлт үйл явдал болоод өнгөрдөг—энэ бүхэн нь Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг хомс байдгаас болдог бус уу? Бурханыг мэддэггүй хүн яаж Түүний өмнө очих нэр нүүртэй байж чадах юм бэ? Бурханд итгэдэг мөртөө Түүнийг хавчдаг хүн яаж Түүний өмнө очих нэр нүүртэй байж чадах юм бэ? Эдгээр нь гагцхүү шашны ертөнц дэх хүмүүсийн хангалтгүй байдал биш, харин та нарт ч, тэдэнд ч аль алинд нь нийтлэг байдаг. Хүмүүс Бурханыг мэдэлгүйгээр Түүнд итгэдэг; ганцхан энэ шалтгааны улмаас тэд зүрх сэтгэлдээ Бурханыг хүндэлдэггүй ба зүрх сэтгэлдээ Түүнээс айж эмээдэггүй. Энэ урсгал дотор өөрсдийн төсөөлсөн ажлыг ил тод, ичгүүр сонжуургүй хийж, Бурханы даалгасан ажлыг өөрсдийн шаардлага, хэрээс хэтэрсэн хүслийн дагуу хийж эхэлдэг хүмүүс ч бий. Олон хүн дураараа аашилж, Бурханыг огт хүндлэхгүйгээр өөрсдийн хүслийг л дагадаг. Эдгээр жишээ нь хүмүүсийн аминчхан зүрх сэтгэлийн төгс илрэл биш гэж үү? Эдгээр жишээ нь хүмүүст байдаг хэт их хууран мэхлэлтийн элементийг харуулдаггүй гэж үү? Хүмүүс үнэндээ гоц ухаантай байж болох ч тэдний авьяас билиг Бурханы ажлыг яаж орлож чадах юм бэ? Хүмүүс үнэндээ Бурханы ачаанд санаа тавьж болох боловч хэтэрхий аминчхан авирлаж болохгүй. Хүмүүсийн үйл хэрэг үнэхээр Бурханлаг гэж үү? Хүн зуун хувь итгэлтэй байж чадах уу? Бурханд гэрчлэл хийж, Түүний алдрыг өвлөн авах—энэ бол Бурхан хүмүүсийг онцгойлон үзэж, өргөж байгаа хэрэг; хүмүүс яаж үнэ цэнтэй байж чадах юм бэ? Бурханы ажил дөнгөж эхэлсэн ба Түүний үг дөнгөж л хэлэгдэж эхэлсэн. Энэ үед хүмүүс өөрсдийгөө сайнаар боддог ч энэ нь ердөө л өөрсдөдөө гутамшиг дуудаж байгаа хэрэг биш үү? Тэд дэндүү багыг ойлгодог. Хамгийн чадварлаг онолч,

хамгийн уран үгтэй илтгэгч хүртэл Бурханы бүхий л элбэг дэлбэг байдлыг дүрсэлж чаддаггүй, тэгвэл та нар үүнээс хэчнээн дор байх билээ? Та нар өөрсдийн үнэ цэнийг тэнгэрээс өндөрт тавих ёсгүй, харин ч өөрсдийгөө, Бурханы хайрыг эрж хайдаг тэр ухаалаг хүмүүсийн алинаас ч илүү дорд хэмээн үзэх ёстой. Өөрсдийгөө бусад бүх хүнээс нэлээд доогуур гэж үзэх нь та нарын орох ёстой зам юм. Яагаад өөрсдийгөө тийм өндөрт тооцно гэж? Яагаад өөрийгөө тийм өндрөөр үнэлнэ гэж? Амийн урт аянд та нар эхний хэдхэн алхмаа л хийсэн. Та нар бүхэл бүтэн Бурханыг биш, Бурханы гарыг л харсан. Дэндүү бага өөрчлөгдсөн учраас та нар Бурханы ажлаас илүү ихийг харж, орох ёстой зүйлээ илүү их олж мэдвэл зохино.

Хүнийг төгс болгож, зан чанарыг нь өөрчлөх Бурханы ажил хэзээ ч зогсдоггүй, учир нь хүн хэтэрхий олон талаар дутуу дулимаг бөгөөд Түүний тогтоосон стандартаас хавьгүй хол байдаг. Иймээс Бурханы нүдэнд та нар үүрд, Түүнд таалагдах маш цөөхөн элемент агуулдаг нярай хүүхдүүд байх болно, учир нь та нар бол ердөө Бурханы гар дахь бүтээлүүд билээ. Хэрвээ хүн маадгар зантай болбол Бурхан зэвүүцэхгүй гэж үү? Өнөөдөр та нар Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чадна гэдэг нь махан биеийн чинь хязгаарлагдмал өнцгөөс хэлэгдсэн байдаг; хэрвээ та нар үнэхээр Бурханы эсрэг тэмцэлдсэн бол дэвжээн дээр үүрд ялагдах байсан. Хүний махан бие хэзээ ч ялалтыг мэдээгүй. Зөвхөн Ариун Сүнсний ажлаар л дамжуулан хүн засаж залруулдаг чанартай байх боломжтой. Үнэн хэрэгтээ Бурханы бүтээл дэх үй олон зүйлээс хүн хамгийн дорд юм. Хэдий хүн бүх зүйлийн эзэн нь боловч тэдгээрийн дундаас ганцхан хүн л Сатаны заль мэхэнд автдаг бөгөөд ганцхан хүн л Сатаны завхралд эцэс төгсгөлгүй урхидуулдаг билээ. Хүн хэзээ ч өөрийгөө захирч байгаагүй. Ихэнх хүн Сатаны балиар заваан газарт амьдарч, түүний доог тохууг амсдаг; Сатан тэднийг хүний ертөнц дэх бүх муу ёр, бүх зовлон бэрхшээлийг туулж, хагас үхлүүт байдалтай болтол нь ийм, тийм маягаар тохуурхдаг. Тэднээр тоглосныхоо дараа Сатан хувь заяаг нь төгсгөл болгодог. Иймээс хүмүүс бүхий л амьдралынхаа турш эргэлзээн дунд мэгдэн гайхширч, өөрсдөд нь зориулан Бурханы бэлдсэн сайхан зүйлсийг нэг ч удаа эдлэлгүй, харин Сатанд хорлогдож, навсайн салбарч үлддэг. Өнөөдөр тэд Бурханы ажлыг анхаарах сөхөөгүй маш сул дорой, үлбэгэр болжээ. Хэрвээ хүмүүс Бурханы ажлыг анзаарах сөхөөгүй бол тэдний туршлага үүрд хагас дутуу, бүрэн бус хэвээр үлдэх тавилантай ба тэдний оролт үүрд хоосон байх болно. Бурхан дэлхийд ирснээс хойших хэдэн мянган жилд, өндөр дээд туйлын хүслэнтэй олон тооны хүн, Бурханы төлөө ажиллахын тулд олон жилийн турш Түүнд ашиглагдсаар ирсэн; гэхдээ Түүний ажлыг мэддэг хүмүүс маш цөөхөн, бараг байдаггүй. Энэ шалтгааны улмаас тоймгүй олон хүн Бурханы төлөө ажиллахын зэрэгцээ Бурханыг эсэргүүцэх үүрэг гүйцэтгэдэг, учир нь Түүний ажлыг хийхийн оронд тэд үнэндээ Бурханы олгосон байр суурин дээр хүний ажлыг хийдэг. Үүнийг ажил гэж нэрлэж болох уу? Тэд яаж орж чадах юм бэ? Хүн төрөлхтөн Бурханы нигүүлслийг аваад, булж орхисон. Үүнээс болж үеэс үед Түүний ажлыг хийдэг хүмүүс өчүүхэн бага оролттой

байдаг. Тэд Бурханы ажлыг мэдэх талаар ердөө ярьдаггүй, учир нь тэд Бурханы мэргэн ухаанаас хэтэрхий багыг ойлгодог. Хэдийгээр Бурханд үйлчилдэг хүн олон байдаг ч Түүний хэр агуу болохыг харж чаддаггүй, ийм учраас л тэд бусдаар шүтүүлэхийн тулд өөрсдийгөө Бурхан мэт өргөмжилдөг.

Маш олон жилийн турш Бурхан бүтээл дотор нуугдмал байсан; маш олон хавар, намар манангийн араас ажигласан; маш олон өдөр, шөнийн турш гуравдагч тэнгэрээс доош харсан; маш олон сар, жилийн турш хүмүүсийн дунд алхсан. Тэрээр бүх хүний дээр суун, маш олон хүйтэн өвлийн турш чимээгүйхэн хүлээсэн. Тэр Өөрийгөө хэнд ч, хэзээ ч ил тод харуулаагүй, ганц ч чимээ гаргаагүй бөгөөд тэмдэг дохиогүйгээр явж, чимээгүйхэн буцан ирдэг. Хэн Түүний үнэн нүүр царайг мэдэж чадах билээ? Тэр хэзээ ч хүнтэй ярьж байгаагүй, хэзээ ч хүнд харагдаагүй. Бурханы даалгасан ажлыг хийх нь хүмүүст хэр амархан байдаг вэ? Бурханыг мэдэх нь бүх зүйлийн дотроос хамгийн хэцүү нь гэдгийг тэд ухаардаггүй. Өнөөдөр Бурхан хүнтэй ярьсан боловч хүн хэзээ ч Түүнийг мэдээгүй, учир нь хүний амийн оролт хэтэрхий хязгаарлагдмал бөгөөд өнгөцхөн. Түүний өнцгөөс харахад, хүмүүс Бурханы өмнө гарч ирэхэд огтхон ч тохирохгүй. Тэд Бурханы талаар дэндүү бага ойлгодог бөгөөд Түүнээс хэтэрхий их холдсон. Түүнчлэн Бурханд итгэх зүрх сэтгэл нь хэтэрхий ярвигтай, мөн тэд Бурханы дүрийг сэтгэлийнхээ гүнд ер хадгалдаггүй. Үүний үр дүнд Бурханы хичээнгүй чармайлт болон ажил нь яг л элсэнд булагдсан алт мэтээр хурц гэрэл цацруулж чаддаггүй. Бурханы хувьд, энэ хүмүүсийн хэв чанар, далд сэдэл, үзэл бодол нь туйлын жигшүүртэй байдаг. Хүлээн авах чадвар нь муудаж, туйлын мэдрэлгүй болж, доройтон дордож, хэтэрхий боол шиг, сул дорой, сэтгэлийн тэнхээгүй болсон тэднийг морь малыг хөтөлдөг шигээр л дөрлөх ёстой. Өөрсдийнхөө сүнсний оролт юм уу Бурханы ажилд орох оролтын тухайд тэд өчүүхэн төдий ч анхаарал хандуулдаггүй ба үнэний төлөө зовох өчүүхэн ч шийдвэр байдаггүй. Ийм төрлийн хүний хувьд Бурханаар бүрэн төгс болгуулах нь яаж амархан байх юм бэ? Тиймээс та нар энэ өнцгөөс өөрсдийн оролтыг эхлэх нь чухал—өөрсдийн ажил болон оролтоор дамжуулан та нар Бурханы ажлыг мэдэж авч эхэлдэг.

АЖИЛ БА ОРОЛТ 2

Та нарын ажил, оролт нэлээд тааруу; хүн, хэрхэн ажиллах тухайд ач холбогдол өгдөггүй бөгөөд амийн оролтын тухайд бүр ч хааш яаш байдаг. Хүн эдгээрийг өөрсдийн орох учиртай хичээл гэж үздэггүй; тиймээс өөрсдийнхөө туршлагаар хоосон зүүд зэрэглээнээс өөрийг бараг хардаггүй. Ажлын тухайд гэвэл, та нараас төдийлөн ихийг шаарддаггүй, харин Бурханаар төгс болгуулах хүний хувиар та нар Бурханы хүсэлд удахгүй нийцэхийн тулд Бурханы төлөө ажиллах хичээлээ сурах учиртай. Эрин үеүдийн туршид ажил хийсэн хүмүүсийг ажилчид, элч нар гэж

нэрлэдэг байсан бөгөөд энэ нь Бурханы ашигладаг цөөн тооны хүнийг хэлдэг үгс юм. Гэвч өнөөдөр Миний ярьж буй ажил гагцхүү энэ ажилчид, элч нарт хамаатай бус, харин ч Бурханаар төгс болгуулах бүх хүнд чиглэдэг. Үүнийг төдийлөн сонирхдоггүй хүн олон байж магад боловч оролтын төлөө энэ асуудлын талаарх үнэнийг ярих зүйтэй юм.

Ажлын тухайд гэвэл, Бурханы төлөө ийш тийш гүйж, хаа сайгүй номлож, Түүний төлөө зарлагадах нь ажил юм гэж хүн боддог. Ингэж бодох нь зөв хэдий ч хэт өрөөсгөл байдаг; Бурхан хүнээс гагцхүү Өөрийнх нь төлөө ийш тийш гүй гэж шаарддаг юм биш; үүнээс гадна, энэ ажил нь сүнсний доторх үйлчлэл, хангалттай хамаатай. Хүний ухан ойлгодог ажил Бурханы шаарддаг зүйлтэй нийцдэггүй учраас энэ олон жилийн туршлагын дараа ч олон ах эгч Бурханы төлөө ажиллах талаар хэзээ ч бодож үзээгүй байдаг. Тиймээс хүн ажил гэх асуудлыг огтхон ч сонирхдоггүй бөгөөд яг энэ шалтгааны улмаас хүний оролт ч бас нэлээд өрөөсгөл байдаг. Та нар бүгд Бурханы төлөө ажиллахаас оролтоо эхлэх ёстой, ингэснээр туршлагын тал бүрийг илүү сайн туулж болох юм. Та нарын орох ёстой зүйл энэ. Ажил гэдэг нь Бурханы төлөө ийш тийш гүйхийг хэлдэг юм биш, харин хүний амь болон хүний амьдран харуулдаг зүйл Бурханд таашаал өгч чаддаг эсэхийг хэлдэг. Ажил гэдэг нь хүмүүс Бурханд үнэнч байдал, Бурханы талаарх мэдлэгээ ашиглан Бурханы тухай гэрчлэх, бас хүнд үйлчлэхийг хэлдэг. Энэ нь хүний хариуцлага төдийгүй бүх хүний ойлгох ёстой зүйл юм. Ажил чинь та нарын оролт бөгөөд Бурханы төлөө ажиллах явцдаа та нар орохоор эрэлхийлж байгаа гэж хэлж болно. Бурханы ажлыг туулна гэдэг нь Түүний үгийг хэрхэн идэж уухаа мэддэг байх төдийхнийг хэлдэггүй; гол нь чи Бурханы талаар хэрхэн гэрчлэхээ мэддэг, Бурханд үйлчилж чаддаг, хүнд үйлчилж, хүнийг хангаж чаддаг байх ёстой. Энэ нь ажил, бас та нарын оролт юм; энэ нь хүн бүрийн гүйцэлдүүлэх ёстой зүйл билээ. Бурханы төлөө ийш тийш гүйж, газар сайгүй номлоход л анхаардаг атлаа хувийн туршлагаа үл анзааран, сүнслэг амьдралд орохоо орхигдуулдаг хүн олон бий. Бурханд үйлчилдэг хүмүүс үүнээс үүдэн Бурханыг эсэргүүцэгчид болсон юм. Ийм олон жил Бурханд үйлчилж, хүнд үйлчилсээр ирсэн энэ хүмүүс ердөө л ажиллаж, номлохыг оролт гэж үзсэн ба хувийн сүнслэг туршлагаа хэн нь ч чухал оролт гэж авч үзсэнгүй. Харин ч тэд Ариун Сүнсний ажлаас авдаг гэгээрлээ бусдад зааж сургах хөрөнгө болгожээ. Номлох үедээ тэд ихээхэн ачаа үүрч, Ариун Сүнсний ажлыг хүлээн авч, үүгээр дамжуулан Ариун Сүнсний дуу хоолойг гаргаж байгаа. Энэ удаа, ажилладаг хүмүүс Ариун Сүнсний ажлыг хувийн сүнслэг туршлагаа болгосон мэт бардамнал дүүрэн байдаг; хэлж буй бүх үг нь өөрсдийнх нь оршихуйд харьяалагддаг гэж тэдэнл санагддаг, тэгсэн атлаа туршлага нь өөрсдийнх нь дүрсэлсэн шиг тодорхой биш байгаа мэт санагддаг. Үүнээс гадна, тэд ярихынхаа өмнө юу гэж хэлэхээ огт мэддэггүй боловч Ариун Сүнс тэдэн дээр ажиллах үед үг нь бэлэн зэлнээр урсан гардаг. Нэг удаа чи ийм маягаар номлочхоод биеийн чинь бодит хэмжээ санасан шиг чинь жаахан биш юм байна гэж боддог бөгөөд Ариун Сүнс чам дээр хэдэнтээ

ажиллачихсан нөхцөлд өөрийгөө аль хэдийн биеийн хэмжээтэй болж гэж үзэн, Ариун Сүнсний ажлыг өөрийнхөө оролт, оршихуй гэж эндүүрэн итгэдэг. Байнга ийм маягаар туршлагажсанаар чи өөрийнхөө оролтод цалгайрч, өөрийн мэдэлгүй залхууралд автан, хувийн оролтдоо ямар ч ач холбогдол өгөхөө болино. Ийм учраас чи бусдад үйлчилж байхдаа өөрийн биеийн хэмжээ, Ариун Сүнсний ажлыг хооронд нь тодорхой ялгаж салгах ёстой. Энэ нь оролтод чинь илүү их тус дөхөм болж, туршлагад чинь улам их үр өгөөж авчирдаг. Хүн Ариун Сүнсний ажлыг хувийнхаа туршлага гэж үзэх нь доройтлын эх сурвалж болдог. Ийм учраас Би, та нар ямар ч үүрэг гүйцэтгэлээ гэсэн, өөрсдийн оролтыг амин чухал хичээл гэж үзэх учиртай гэж хэлдэг юм.

Бурханы хүслийг хангалуун байлгаж, Бурханы зүрх сэтгэлийн дагуух бүх хүнийг Түүний өмнө авчирч, хүнийг Бурхан руу аваачиж, Ариун Сүнсний ажил болон Бурханы удирдамжийг хүнд танилцуулж, улмаар Бурханы ажлын үр жимсийг төгс болгохын тулд хүн ажилладаг. Иймээс та нар ажлын мөн чанарыг нэгд нэггүй тодорхой мэдэх шаардлагатай. Бурханы ашигладаг хүн болохын хувьд хүн бүр Бурханы төлөө ажиллах үнэ цэнтэй, өөрөөр хэлбэл, Ариун Сүнсээр ашиглуулах боломжтой. Гэвч та нарын ухаарах ёстой нэг зүйл бий: Бурханы даалгасан ажлыг хийх үед хүнд Бурханаар ашиглуулах боломж олдсон боловч хүний хэлдэг, мэддэг зүйл нь тэр чигтээ хүний биеийн хэмжээ байдаг юм биш. Ажлынхаа явцад дутагдлаа илүү сайн мэдэж авч, Ариун Сүнсний улам их гэгээрлийг эзэмших нь л та нарын хийж чадах зүйл юм. Ийм маягаар та нар ажлынхаа явцад илүү сайн орох боломжтой болно. Хэрвээ хүн Бурханаас ирдэг удирдамжийг өөрийн оролт, өөрт нь төрөлхөөсөө байдаг зүйл гэж үзвэл хүний биеийн хэмжээ өсөх бололцоо байхгүй. Хүнийг хэвийн байдалд байх үед Ариун Сүнс гэгээрэл хайрладаг; ийм үед хүмүүс хүлээж авсан гэгээрлээ өөрсдийн биеийн бодит хэмжээ гэж үргэлж андуурдаг, учир нь Ариун Сүнсний гэгээрүүлдэг байдал гойд хэвийн бөгөөд хүний дотор төрөлхөөсөө байдаг зүйлийг ашигладаг. Хүмүүсийг ажиллаж, үг хэлэх үед эсвэл залбирч, сүнслэг үйл ажиллагаа явуулах үед үнэн гэнэт тодорхой болно. Гэвч бодит байдал дээр хүний хардаг зүйл нь зөвхөн Ариун Сүнсний гэгээрэл (мэдээж энэ гэгээрэл нь хүний хамтын ажиллагаатай холбоотой) бөгөөд хүний биеийн жинхэнэ хэмжээг төлөөлдөггүй. Зарим нэг бэрхшээл, шалгалттай тулгардаг хэсэг хугацааны туршлагын дараа хүний биеийн жинхэнэ хэмжээ тийм нөхцөлд илэрхий болдог. Тэр үед л хүн биеийн хэмжээ нь төдийлөн сайнгүйг олж мэдэн, аминч зан, амин хувиа гэх бодол, шунал нь бүгд гарч ирдэг. Ийм туршлагын хэд хэдэн мөчлөгийн дараа л, урьд нь туулсан зүйлс өөрсдийнх нь бодит байдал бус, харин Ариун Сүнснээс ирсэн агшин зуурын гэрэлтүүлэлт байсан бөгөөд хүн энэ гэрлийг хүлээн авснаас цаашгүй гэдгийг сүнсээрээ сэрсэн олон хүн ухаарна. Ариун Сүнс аливааг хэрхэн бий болсон, хааш явж буйг тайлбарлалгүй тодорхой, ялгарахуйц байдлаар хүнийг гэгээрүүлэн үнэнийг ойлгуулдаг. Өөрөөр хэлбэл, хүний бэрхшээлийг энэ илчлэлд нэгтгэхийн оронд үнэнийг шууд илчилдэг. Хүн орох явцдаа

бэрхшээлтэй тулгараад Ариун Сүнсний гэгээрлийг нэгтгэвэл энэ нь хүний бодит туршлага болдог. Жишээлбэл, гэрлээгүй нэг эгч нөхөрлөлийн үеэр ингэж ярьсан юм: “Бид алдар суу, эд баялаг хөөцөлддөггүй, мөн эхнэр нөхрийн хоорондох хайр сэтгэлийн жаргалд ч шунадаггүй; харин гагцхүү ариун, нэгэн үзүүрт зүрх сэтгэлээ Бурханд зориулахаар л эрэлхийлдэг.” Тэр эгч цааш нь үргэлжлүүлэн: “Хүмүүс гэрлэмэгц олон зүйл тэднийг зүдрээж, Бурханыг хайрлах сэтгэл нь чин үнэнч байхаа больдог. Зүрх сэтгэлийг нь гэр бүл, хань ижил нь үргэлж эзэмдэж байдаг тул тэдний дотоод ертөнц улам илүү ээдрээтэй болдог …” гэсэн юм. Ингэж ярьж байхдаа тэр эгч сэтгэлдээ боддог зүйлээ амаараа хэлж буй мэт байсан юм; эгчийн хэлсэн үг бүхэн зүрх сэтгэлийнх нь угаас гарсан мэт, Бурханд өөрийгөө бүрэн зориулъя гэж үнэн голоосоо хүсэж, бусад ах эгч өөртэй нь адилхан шийдвэртэй байгаасай гэж найддаг мэт үг нь цангинасан, хүчирхэг байлаа. Ийм мөчид сэтгэл шулуудах, сэтгэл хөдлөх мэдрэмж чинь тэр чигтээ Ариун Сүнсний ажлаас гардаг гэж хэлж болно. Бурханы ажлын арга барил өөрчлөгдөх үед нас чинь ч бас хэдээр нэмэгдсэн байх болно; ангийнхан, үе тэнгийн найз нөхөд чинь бүгд нөхөрт гарсныг чи харж, эсвэл хэн нэг нь гэрлэснийхээ дараа ханьтайгаа хамт хотод амьдрахаар яваад тэндээ ажилд орсон гэхийг сонсдог. Түүнтэй уулзаад, хөлнөөсөө толгой хүртлээ дур булаам, хээнцэр байдлаар дүүрэн байгааг нь хараад чи атаархаж эхэлнэ, мөн чамтай ярилцахдаа орчин үеийн хэв маягтай, хөдөөний хөөсөн мантуу гэх ямар ч шинжгүй болсон байгааг харна. Үүнийг хараад чамд олон мэдрэмж төрнө. Энэ бүх хугацаанд Бурханы төлөө өөрийгөө зарлагадсан чи гэр бүл ч үгүй, ажил мэргэжил ч үгүй байгаа бөгөөд асар их харьцалт туулжээ; хэсэг хугацааны өмнө дунд эргэм насанд хүрээд, орь залуу нас чинь аль хэдийн зүүд зэрэглээ мэт чимээгүйхэн өнгөрөн оджээ. Тэгээд өдий хүртэл явчхаад чи хаана төвхнөхөө мэддэггүй. Энэ мөчид чи ухаанаа алдсан мэт бодолд автана. Орь ганцаар, унтаж чадалгүй бүхий л шөнөжин сэрүүн хэвтэх үедээ нэг л мэдэхэд чи гаргасан шийдвэр, Бурханд өгсөн ариун тангаргаа бодож эхэлдэг, тэгсэн мөртөө яагаад ийм хөөрхийлөлтэй байдалд уначихсан юм бэ? Чи өөрийн мэдэлгүй чимээгүйхэн нулимс унагаж, өр өвтгөм шаналал мэдэрдэг. Бурханы өмнө залбирахаар очоод Бурхантай хамт байсан өдрүүддээ хэчнээн ойр, салшгүй дотно байснаа санана. Дүр зургууд нүдний чинь өмнө ар араасаа хөвөрч, “Бурхан миний цор ганц дотнын нэгэн бус уу?” гэх тэр өдөр өгсөн тангараг чинь чихэнд чинь дахин нэгэнтээ хангинана. Тэр үед чи аль хэдийн цурхиртлаа уйлж: “Бурхан минь! Хайрт Бурхан минь! Танд би аль эрт бүхий л зүрх сэтгэлээ өгчихсөн. Танд би үүрд амламаар байна, мөн Таныг насан туршдаа тууштай хайрлана …” хэмээнэ. Тийм хүнд зовлонд тэмцэлдэж байхдаа л чи Бурхан хэчнээн хайр татам болохыг үнэхээр мэдэрч, Бурханд аль эрт бүхнээ өгсөн юм байна гэдгээ гагцхүү тэр үед л тодорхой ухаардаг. Ийм цохилтыг давсныхаа дараа чи эдгээр асуудлын тухайд хавьгүй илүү боловсорч, тухайн үеийн Ариун Сүнсний ажил хүний эзэмшсэн зүйл биш байсныг хардаг. Энэ үеэс хойших туршлагадаа чи оролтын энэ талд хязгаарлагдахаа

болино; хуучин шархнаас чинь үлдсэн сорви чиний оролтод асар их ашиг тус өгсөн мэт байдаг. Ийм нөхцөл байдалтай тулгарах бүрдээ чи салж хагацсаныхаа дараа Бурхантай эргэн уулзсан мэт тэр өдөр унагасан нулимсаа даруй санаж, Бурхан та хоёрын харилцаа дахин тасрах вий, Бурхан та хоёрын сэтгэлийн холбоонд (хэвийн харилцаанд) дахин сэв суух вий гэж цаг ямагт айх болно. Энэ нь чиний ажил, оролт юм. Тиймээс, Ариун Сүнсний ажлыг хүлээн авахын зэрэгцээ Ариун Сүнсний ажил гэж яг юу болох, та нарын оролт гэж юу болохыг харж, мөн Ариун Сүнсний ажлыг оролтдоо нэгтгэн оролтдоо улам их ач холбогдол өгөх учиртай, ингэснээр Ариун Сүнс та нарыг илүү олон аргаар төгс болгож, Ариун Сүнсний ажлын мөн чанар та нарын дотор шингэж болох юм. Ариун Сүнсний ажлыг туулах явцдаа та нар Ариун Сүнсийг болон өөрсдийгөө мэддэг болох төдийгүй тоймгүй олон удаагийн хүнд зовлон дунд Бурхантай хэвийн харилцаа тогтоож, Бурхан та хоёрын харилцаа өдөр ирэх тусам ойртон дотносно. Тоо томшгүй олон удаагийн засалт, цэвэршүүлэлтийн дараа Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг болно. Тийм учраас та нар зовлон, цохилт, гай зовлонгоос айх хэрэггүй гэдгийг ухаарах ёстой; Ариун Сүнсний ажилтай атлаа оролтгүй байх л аймшигтай. Бурханы ажил дуусах өдөр ирэхэд чи шал дэмий хөдөлмөрлөсөн байх болно; Бурханы ажлыг туулсан хэдий ч чи Ариун Сүнсийг мэдэж аваагүй, өөрийн гэсэн оролттой болоогүй байх болно. Ариун Сүнсний өгдөг гэгээрэл нь хүний хүсэл тэмүүллийг тэтгэх бус, харин хүний орох замыг нээх, мөн Ариун Сүнсийг мэдэж аваад, улмаар Бурханыг гэх хүндлэл, бишрэлтэй болох боломжийг хүнд олгохын төлөө байдаг билээ.

АЖИЛ БА ОРОЛТ 3

Бурхан хүмүүст ихийг даалгаж, тэдний оролтыг тоймгүй олон байдлаар ярьсан. Гэвч хүмүүсийн хэв чанар нэлээд дорой тул Бурханы олон үг жинтэй тусаж чадаагүй юм. Хүний бодол болон ёс суртахууны ялзрал, зохистой хүмүүжил дулимаг байдал; хүний зүрх сэтгэлийг лавтай эзэмдсэн бурангуй нийгмийн мухар сүсэг; хүний зүрх сэтгэлийн гүн чанадад олон муу муухайг суулгасан гажууд, задарсан амьдралын хэв маяг; хүмүүсийн бараг ерэн найман хувь нь соёлын боловсролгүй байхаас гадна тун цөөхөн хүн л арай өндөр түвшний соёлын боловсрол эзэмшдэг, соёлын өнгөц мэдлэг гэх зэрэг олон янзын шалтгаанаас энэхүү дорой хэв чанар үүдэлтэй. Иймээс Бурхан, Сүнс гэж юу гэсэн утгатайг хүмүүс үндсэндээ огт мэддэггүй, харин гагцхүү бурангуй нийгмийн мухар сүсгээс Бурханы талаар тодорхойгүй, бүрхэг дүр зураг олж авсан байдаг. Мянган мянган жилийн “үндэсний үзлийн сүрлэг чанараас” хүний зүрх сэтгэлд гүн үлдсэн хорт нөлөө болон бурангуй нийгмийн сэтгэлгээ нь хүмүүсийг өчүүхэн ч эрх чөлөөгүй, тэмүүлж чармайх ямар ч хүсэлгүй, өсөн дэвжих ямар ч эрмэлзэлгүй, харин ч идэвхгүй, доройтмол, боолын сэтгэлгээнд автсан байдалтай болгон хүлж дөнгөлдөг

бөгөөд эдгээр бодит хүчин зүйл нь хүн төрөлхтний үзэл суртлын төлөв байдал, туйлын зорилго, ёс суртахуун, зан чанарыг арилшгүй бузар, үзэшгүй муухай хэлбэртэй болгожээ. Хүмүүс терроризмын харанхуй ертөнцөд амьдарч буй бөгөөд үүнийг даван гарахыг хэн нь ч эрэлхийлдэггүй, өв тэгш ертөнцөд хүрэх тухай хэн нь ч боддоггүй мэт санагдана; харин ч тэд амьдрал дахь өөрсдийн хувь зохиолд сэтгэл ханаж, үр хүүхэд төрүүлж өсгөн, махран зүтгэж, хөлсөө урсгаж, гэр орны ажлаа амжуулж, тав тухтай, аз жаргалтай гэр бүл мөрөөсөж, ханийн хайр, ачлалт үр хүүхэд, өтөл насандаа тайван амьдрангаа баяр баясалтай байхыг хүсэмжлэн өдөр хоногоо элээдэг… Өнөөг хүртэл олон арав, олон мянган, олон түмэн жилийн турш хүмүүс ийм маягаар цагаа үрж, хэн ч төгс амьдрал босголгүйгээр, энэхүү харанхуй ертөнцөд бүгд нэгнээ хөнөөх, алдар нэр, эд хөрөнгийн төлөө уралдах, бие биеийнхээ эсрэг далд явуулга хийхийг л зорьсоор ирсэн. Бурханы хүслийг хэн ер нь эрж хайсан юм бэ? Бурханы ажлыг ер нь хэн анхаарч үзсэн юм бэ? Харанхуйн нөлөөнд автсан хүн төрөлхтний бүх хэсэг аль эртнээс хүний уг чанар болсон тул Бурханы ажлыг биелүүлэх нэлээд хэцүү бөгөөд өнөөдөр Бурханы даалгасан зүйлийг анхаарах зүрх сэтгэл хүмүүст бүр ч бага байдаг. Ямартай ч Би олон мянган жилийн түүхийг ярьж буй тул ийм үг айлдаж байгаад минь хүмүүс дургүйцэхгүй биз. Түүх ярина гэдэг нь баримт, мөн түүнчлэн бүгдэд илэрхий дуулиан шуугиан гэсэн үг тул баримтаас зөрсөн юм ярих ямар хэрэг байх вэ? Бас ухаалаг хүмүүс эдгээр үгийг хараад сэрж, ахиц гаргахаар чармайна гэж Би итгэж байна. Хүмүүс амар амгалан, сэтгэл хангалуун ажиллаж, амьдрахын зэрэгцээ Өөрийг нь хайрлаж чадна гэж Бурхан найддаг. Бүх хүн төрөлхтөн амралтад ороосой гэж Бурхан хүсдэг; гол нь бүхий л газар нутгийг Өөрийн алдар суугаар дүүргэх нь Бурханы агуу хүсэл билээ. Гэвч хүмүүс мартагналд автаад сэрэхгүй, Сатаны завхралд маш ноцтой өртөөд өнөөдөр хүний төрхгүй болсон нь харамсалтай. Иймээс хүмүүсийн соёлын хэв чанарыг сайжруулж, сүнслэг төлөв байдлыг нь өөрчлөхөд хүний бодол, ёс суртахуун, боловсрол чухал холбоосыг бүрдүүлдэг ба соёлын мэдлэгт суралцах нь хоёр дахь холбоосыг бүрдүүлдэг.

Үнэндээ хүн төрөлхтөнд тавьдаг Бурханы шаардлага тийм ч өндөр биш, харин хүмүүсийн хэв чанар болон Бурханы шаарддаг стандартын хоорондох зөрүү маш их учраас ихэнх хүн зүгээр л толгойгоо өргөн, Бурханы шаардлагын чигт хардаг боловч тэдгээрийг биелүүлэх чадвар дутагддаг. Хүмүүсийн төрөлхийн авьяас билиг, төрсний дараа олж авсан зүйлс нь хамтдаа Бурханы шаардлагыг биелүүлэхэд ер хангалтгүй байдаг. Гэвч энэ асуудлыг зүгээр л ухаарна гэдэг гарцаагүй шийдэл биш. Алсын ус өнөөгийн цангааг тайлж чадахгүй. Хүмүүс тоос шорооноос дорд гэдгээ мэдлээ ч гэсэн Бурханы сэтгэлийг хангалуун байлгахаар сэтгэл шулуудахгүй, Бурханы шаардлагыг хангах дэвшилтэт замаар бүр ч явахгүй бол тийм мэдлэг ямар үнэ цэнтэй юм бэ? Усыг шүүрэн шанагаар хутгах адил ямар ч нэмэргүй бус уу? Миний хэлж байгаа зүйл гол нь оролттой холбоотой; энэ бол үндсэн сэдэв юм.

Хүний оролтын явцад амьдрал ямагт уйтгартай байж, залбирах, Бурханы үгийг идэж уух, цуглаан хийх гэх мэт сүнслэг амьдралын нэгэн хэвийн элементээр дүүрэн байдаг тул хүмүүст Бурханд итгэх нь их баяр баясал огт өгдөггүй мэт цаг ямагт санагддаг. Ийм сүнслэг үйл ажиллагаа нь Сатаны завхруулсан, хүн төрөлхтний анхдагч зан чанарт үндэслэн явагддаг. Хүмүүс зарим үед Ариун Сүнсний гэгээрлийг хүртэж чаддаг ч анхдагч сэтгэлгээ, зан чанар, амьдралын хэв маяг, зуршил нь тэдний дотор үндэслээтэй хэвээр байдаг тул уг чанар нь өөрчлөгдөлгүй үлддэг. Хүмүүсийн хийдэг мухар сүсэгт үйл ажиллагааг Бурхан хамгийн их үзэн яддаг ч олон хүн тэдгээрийг мөн л орхиж чадалгүй, ийм мухар сүсэгт үйл ажиллагааг Бурхан зарлигдсан гэж бодож байдаг бөгөөд өнөөдөр ч тэдгээрээс хараахан бүрэн ангижраагүй байна. Хурим найр, сүйт бүсгүйн хувцас сэлтэд зориулан залуучуудын хийдэг бэлтгэл; мөнгө бэлэглэх, оройн зоог барих гэх мэтээр баярт үйл явдлыг тэмдэглэдэг арга зам; уламжлагдаж ирсэн эртний заавар; үхэгсэд болон тэдний оршуулгын үйлд зориулан хийдэг мухар сүсэгт утгагүй бүх арга хэмжээг Бурхан бүр ч их жигшдэг. Мөргөлийн өдөр ч (шашны ертөнцийн тэмдэглэдэг Амралтын өдрийг оролцуулан) Бурханд жигшүүртэй байдаг; мөн хүн хооронд өрнөдөг нийгмийн харилцаа, дэлхий ертөнцийн холбоо сүлбээг Бурхан бүр ч их жигшин голдог. Хүн бүхний мэдэх цагаан сар, зул сарын баяр байтугай эдгээр баяр наадамд зориулсан тоглоом, чимэглэл болох хоёр мөрт шүлэг, салют, дэнлүү, Ариун Зоог, зул сарын бэлэг, зул сарын баяр наадмыг ч Бурхан зарлигдаагүй—эдгээр нь хүмүүсийн оюун ухаан дахь шүтээн бус уу? Амралтын өдрөөр талх хуваах, дарс, нарийн маалинга бол шүтээн гэдэг нь бүр ч гарцаагүй. Лууны толгой өнгийх өдөр, луун завины баяр, намрын дунд сарын баяр, Лаба наадам, шинэ оны баяр гэх зэрэг Хятадад алдартай бүхий л уламжлалт баяр наадмын өдөр, мөн Улаан өндөгний баяр, Баптисмын өдөр, зул сарын баяр гэх зэрэг шашны ертөнцийн баяр наадмууд, энэ бүх үндэслэлгүй баярыг олон хүн эрт цагаас өнөө үед бэлтгэж, уламжилсан. Хүн төрөлхтний баялаг төсөөлөл, уран яруу үзлээс үүдэн эдгээр нь өнөөг хүртэл уламжлагдаж ирсэн юм. Эдгээр нь өө сэвгүй харагддаг ч үнэндээ хүн төрөлхтөнд гаргадаг Сатаны заль мэх байдаг. Сатанууд бөөгнөрсөн газар байх тусмаа хоцрогдмол, хуучинсаг, бурангуй нийгмийн ёс заншилд улам гүн автсан байдаг. Эдгээр зүйл хүмүүсийг чанга хүлчхээд хөдлөх ямар ч боломж өгдөггүй. Шашны ертөнцийн олон баяр наадам ихээхэн өвөрмөц байдлыг харуулж, Бурханы ажилд хүрэх гүүр болж буй санагддаг ч үнэндээ тэдгээр нь хүмүүсийг хүлж, Бурханыг мэдэж авахад нь саад хийдэг Сатаны үл үзэгдэх хүлээс бөгөөд бүгд Сатаны зальхай явуулга юм. Үнэндээ Бурханы ажлын нэг үе шат дуусахад тухайн үеийн хэрэгсэл, хэв маягийг Бурхан аль хэдийн ямар ч ул мөр үлдээлгүй устгасан байдаг. Гэвч “үнэн сүсэгт итгэгчид” өнөөх биет материаллаг зүйлсийг үргэлжлүүлэн шүтэхийн зэрэгцээ Бурханд юу байгааг чухалчилж үзэхээ болин, цааш үл судалдаг бөгөөд үнэндээ Бурханыг аль эрт гэрээс хөөн гаргаж, Сатаныг шүтээний ширээндээ залсан атлаа Бурханыг гэх хайраар бялхаж буй мэт санагддаг. Хүмүүс Есүс,

Загалмай, Мариа, Есүсийн баптисм, Сүүлчийн Зоогийн хөргийг Тэнгэрийн Эзэн хэмээн дээдлэх зууpаа “тэнгэрлэг Эцэг, Эзэн минь” гэж удаа дараа дуу алддаг. Энэ бүхэн хөгийн хэрэг бус уу? Өнөөдрийг хүртэл хүн төрөлхтний дунд өвлөгдөж ирсэн ийм олон үг хэллэг, зан үйлийг Бурхан үзэн яддаг; тэдгээр нь Бурханы өмнөх замд ноцтой саад хийхийн зэрэгцээ хүн төрөлхтний оролтод асар их хүндрэл үүсгэдэг. Сатан хүн төрөлхтнийг завхруулсан хэр хэмжээг хойш тавилаа гэхэд Витнесс Лигийн хууль, Лоренсийн туршлага, Вочман Нигийн судалгаа, Паулын ажил гэх мэт зүйлээр хүний сэтгэл бүрэн дүүрсэн байдаг. Хүмүүсийн дотор хэт их бодгальч үзэл, хууль тогтоомж, дүрэм, журам, тогтолцоо гэх мэт оршин байдаг тул Бурхан хүмүүс дээр ажиллах ямар ч аргагүй; хүмүүсийн бурангуй нийгмийн мухар сүсэгт хандлагаас гадна эдгээр зүйл хүн төрөлхтнийг барьж залгисан юм. Хүмүүсийн бодол санаа нь шидэт үлгэрийг өнгөтөөр өгүүлэх сонирхол татам кино мэт байдаг бөгөөд үүнд нь гайхамшигт амьтад үүл хөлөглөж, асар их уран сэтгэмжээрээ хүмүүсийг гайхшируулж, мэл гайхуулан хэлэх үггүй болгодог. Үнэнийг хэлэхэд өнөөдөр Бурханы хийх гэж ирсэн ажил нь үндсэндээ хүмүүсийн мухар сүсэгт шинж чанартай харьцаж, үүнийг нь арилгах, сэтгэх өнцгийг нь бүрмөсөн өөрчлөх явдал юм. Хүн төрөлхтний үе дамжин уламжилсан өвөөс үүдэн Бурханы ажил өнөөг хүртэл үргэлжилсэн юм биш; энэ нь Бурханы биечлэн эхлүүлж, гүйцэлдүүлдэг ажил бөгөөд тодорхой нэг агуу сүнслэг хүний өвийг өвлөж, өөр эрин үед Бурханы хийсэн бэлгэдлийн уг чанартай аливаа ажлыг өвлөн авах ямар ч шаардлагагүй. Хүмүүс эдгээрийн алинд ч анхаарах хэрэггүй. Өнөөдөр Бурхан үг хэлж, ажиллах өөр хэв маягтай байхад хүмүүс юунд өөрсдөдөө төвөг удах ёстой юм бэ? Хэрэв хүмүүс одоогийн урсгал дахь өнөөгийн замаар алхангаа “өвөг дээдсийнхээ” өв уламжлалыг үргэлжлүүлэх юм бол хүрэх газартаа очихгүй. Бурхан хүний ертөнцийн жил, сар, өдөр хоногийг жигшдэгийнхээ адилаар хүний зан авирын яг ийм горимыг гүнээ зэвүүцдэг.

Хүний зүрх сэтгэлийн чанад дахь гүнээ хордсон хэсгийг анагаан, хүмүүст сэтгэлгээ, ёс суртахуунаа өөрчилж эхлэх боломж олгох нь хүний зан чанарыг өөрчлөх хамгийн сайн арга юм. Энэ бүх шашны зан заншил, үйл ажиллагаа, жил сар, баяр наадмыг Бурхан үзэн яддаг гэдгийг хүмүүс юун түрүүнд тодорхой ойлгох хэрэгтэй. Тэгээд бурангуй нийгмийн сэтгэлгээний эдгээр хүлээсээс мултарч, мухар сүсэгт гүнээ дурладаг бүхий л ул мөрөө арилгах ёстой. Энэ бүгд хүн төрөлхтний оролтод багтдаг. Бурхан хүн төрөлхтнийг шашны бус ертөнцөөс юунд гаргадаг, мөн дүрэм журмаас юунд холдуулдгийг та нар ойлгох ёстой. Та нарын орох үүд хаалга энэ бөгөөд эдгээр зүйл сүнслэг туршлагатай чинь огт хамаагүй боловч Бурханыг мэдэхэд чинь саад хийн, оролтыг чинь хааж буй хамгийн том саад юм. Эдгээр нь хүмүүсийг урхиддаг торыг бүрдүүлдэг. Олон хүн Библийг хэт их уншин, Библийн олон тооны эшлэлийг бүр цээжээр хэлж чаддаг. Өнөөдөр хүмүүс Бурханы ажил дахь энэ үе шатын үндэслэл нь Библид байдаг, үүний эх сурвалж нь Библи мэтээр өөрсдийнхөө оролтод Бурханы ажлыг өөрийн эрхгүй Библиэр хэмждэг. Бурханы ажил Библитэй нийцэх үед хүмүүс Бурханы ажлыг шийдвэртэйгээр дэмжин, Түүнийг

урьд байгаагүйгээр хүндэлж үздэг; Бурханы ажил Библиэс зөрөх үед хүмүүс тун их түгшиж, хүйтэн хөлс нь бурзайн, Бурханы ажлын үндэслэлийг Библиэс хайдаг; хэрэв Бурханы ажлыг Библид огт дурдаагүй байвал хүмүүс Бурханыг үл ойшооно. Бурханы өнөөгийн ажлын тухайд бол ихэнх хүн хянуур, сэрэмжтэйгээр хүлээн зөвшөөрч, дуртай үедээ дуулгавартай дагаж, үүнийг мэдэх явдлыг үл ойшоодог; харин өнгөрч баларсан зүйлсийн тухайд хүмүүс нэг талтай нь зууралдан нөгөөг нь орхидог гэж хэлж болох юм. Үүнийг оролт гэж болох уу? Бусдын номыг эрдэнэс мэт үзэж, хаанчлалын хаалганы алтан түлхүүр мэт хандах хүмүүс өнөөдөр Бурханы өөрсдөөс нь шаарддаг зүйлийг үнэндээ огт сонирхдоггүй. Түүнчлэн олон “ухаалаг шинжээч” Бурханы үгийг зүүн гартаа барьж, бусдын “суут бүтээлийг” баруун гартаа барьчхаад Бурханы үг зөв гэдгийг бүрэн нотлохын тулд энэхүү суут бүтээл дотроос Бурханы өнөөгийн үгийн үндэслэлийг олох хүсэлтэй мэт байдаг бөгөөд тэр ч бүү хэл ажиллаж буй мэтээр Бурханы үгийг суут бүтээлтэй нэгтгэн тайлбарладаг. Үнэнийг хэлэхэд өнөөгийн шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн ололт, урьд өмнө нь байгаагүй амжилтыг (өөрөөр хэлбэл Бурханы ажил, Бурханы үг, амийн оролтын замыг) хэзээ ч их юманд авч үзэж байгаагүй “эрдэмтэн судлаачид” хүн төрөлхтний дунд олон тул хүмүүс бүгд “биеэ дааж”, уран яруу үгийнхээ хүчээр энд тэндгүй “номлож”, “Бурханы сайн нэрээр” гайхуулж байдаг. Энэ хооронд өөрсдийнх нь оролт аюулд орж, бүтээлийн үеэс энэ мөч хүртэлх зай шиг Бурханы шаардлагаас хол хөндий болсон мэт байдаг. Бурханы ажлыг хийх хэр амархан бэ? Хүмүүс өөрсдийнхөө нэг хагасыг өчигдөртөө үлдээн, нөгөө хагасыг нь өнөөдөртөө авчирч, хагасыг нь Сатанд хүргэн, хагасыг нь Бурханд өргөн барья гэж аль хэдийн шийдчихсэн мэт байдаг бөгөөд энэ нь мөс чанараа уужруулж, жаахан тайтгарал авах арга мэт санагддаг. Хүмүүсийн дотоод ертөнц маш их дотуур тамиртай бөгөөд маргаашаас гадна өчигдрийг алдах вий гэж айн, байгаа ч юм шиг, байхгүй ч юм шиг өнөөдрийн Бурхан, Сатан хоёрын хэн хэнийг нь гомдоохоос ихэд эмээж байдаг. Хүмүүс сэтгэхүй, ёс суртахуунаа зохих ёсоор хөгжүүлж чадаагүй тул ялган таних чадвараар нэн дулимаг бөгөөд өнөөдрийн ажил Бурханых мөн эсэхийг огт хэлж мэддэггүй. Магадгүй бурангуй нийгмийн, мухар сүсэгт сэтгэлгээ нь асар гүн учраас хүмүүс аль эртнээс мухар сүсгийг үнэнтэй, Бурханыг шүтээнтэй нэг ангилалд оруулж ирсэн бөгөөд эдгээрийг хооронд нь ялгая гэж боддоггүй, мөн тархиа гашилгаад ч тодорхой ялгаж салгаж чадахгүй мэт байдаг. Иймээс хүмүүс замдаа зогсчхоод урагшлахаа больсон юм. Хүмүүс үзэл суртлын зөв боловсролгүй байдгаас энэ бүх асуудал үүсдэг бөгөөд энэ нь хүмүүсийн оролтод асар их хүндрэл учруулдаг. Улмаар хүмүүс жинхэнэ Бурханы ажлыг хэзээ ч сонирхдоггүй атлаа хүний (тухайлбал, өөрсдийн агуу гэж үздэг хүмүүсийн) ажлаар тамгалуулчихсан мэт үүнтэй тууштай зууралддаг[1]. Эдгээр нь хүмүүсийн орох ёстой хамгийн сүүлийн үеийн сэдэв бус уу?

[1] “Тууштай зууралддаг” гэдгийг егөөдөн ашигласан болно. Энэ хэлц нь хүмүүсийн зөрүүд, үг авдаггүй, хуучирсан зүйлстэй зууралдаж, тавьж явуулах хүсэлгүй байдлыг илтгэдэг.

АЖИЛ БА ОРОЛТ 4

Хэрвээ хүн Ариун сүнсний ажлын дагуу үнэхээр орж чадвал түүний амь хаврын бороонд дараах хулсны нахиа шиг хурдан ургана. Ихэнх хүмүүсийн одоогийн биеийн хэмжээнээс харах юм бол хүмүүс амийг огт чухалчилдаггүй, харин ямар ч ач холбогдолгүй харагддаг тодорхой асуудлуудыг чухалчилдаг. Эсвэл тэд ийш тийш яаравчилж, зорилгогүйгээр, хааш яаш, анхаарал төвлөрөөгүй байдалтай ажиллаж, хэний төлөө вэ гэдгээ мэдэх нь байтугай, аль зүгт явах ёстойгоо ч мэддэггүй. Тэд зүгээр л “өөрсдийгөө даруухнаар нууж” байдаг. Үнэндээ, та нарын дотроос цөөн хэд нь л эцсийн өдрүүд дэх Бурханы санаа зорилгын талаар ямар нэг юм мэдэж байдаг. Та нараас тун цөөхөн нь л Бурханы мөрийг мэддэг, гэхдээ түүнээс ч дор зүйл бол Бурхан эцэстээ юу хийж гүйцэлдүүлэхийг хэн ч мэддэггүй. Гэсэн ч хүн бүхэн сэтгэлийн тэнхээ, тэвчээрээрээ бусдын сахилгажуулалт, харьцалтыг туулж, ялах цагаа хүлээн булчингаа чангалж, тэмцэлд бэлтгэж[1] байгаа мэт байдаг. Хүмүүсийн дундах энэ “хачин үзвэрүүдэд” Би ямар ч тайлбар хийхгүй, гэхдээ та бүгдийн ойлгох ёстой нэг зүйл бий. Яг одоо ихэнх хүмүүс хэвийн бус байдалтай[2] болж байгаа ба оролт руу алхахдаа мухардал[3] руу алхаж байна. Энэ нь хүний хүсэн хүлээдэг, хүмүүний ертөнцийн гаднах утопи мөн хэмээн бодож, үүнийг эрх чөлөөний ертөнц гэж үздэг хүн олон байж магадгүй боловч үнэн хэрэгтээ энэ нь тийм биш. Эсвэл магадгүй, хүмүүс аль хэдийн замаа алдсан гэж хэлж болох юм. Гэхдээ хүмүүс юу хийж байгаагаас үл хамааран Би хүний орох ёстой зүйл юу болох талаар мөн л яримаар байна. Үй олон хүний гавьяа, дутагдал нь энэ ярианы үндсэн сэдэв биш. Ах эгч та бүгд Миний үгийг зөвөөр хүлээн авч, санаа зорилгыг минь буруугаар ойлгохгүй байж чадна гэж Би найдаж байна.

Хонконг, Тайвань дахь эх орон нэгтнүүдийнх нь хэлдгээр “дотор газар” буюу Хятадын эх газарт Бурхан бие махбодтой болсон. Бурхан дээд тэнгэрээс газар луу ирэх үед тэнгэр газар дахь хэн ч үүнийг мэдээгүй, учир нь энэ бол Бурхан нууцаар эргэн ирэхийн жинхэнэ утга учир юм. Тэрээр удаан хугацаанд махбодоор ажиллаж, амьдарсаар ирсэн атал хэн ч үүнийг мэдээгүй. Өнөөдөр ч гэсэн хэн ч үүнийг танин мэддэггүй. Магадгүй энэ нь мөнхийн оньсого хэвээр үлдэнэ. Бурхан энэ удаа махбодод ирсэн нь нэг ч хүний мэдэж чадах зүйл биш юм. Сүнсний ажлын үр нөлөө хэчнээн өргөн цар хүрээтэй, хүчтэй байх нь хамаагүй, Бурхан үргэлж тайван хэвээр байж, хэзээ ч юу ч хэлээгүй. Бурханы ажлын энэ үе шат тэнгэрлэг ертөнцөд явагдаж байгаа мэт байдаг гэж хэлж болно: Хэдийгээр энэ нь харах нүдтэй хүн бүхэнд илэрхий байдаг боловч хэн ч үүнийг таньж мэддэггүй. Бурхан Өөрийнхөө

---

[1] “Булчингаа чангалж, тэмцэлд бэлдэх” гэдгийг тохуурхан хэлсэн.

[2] “Хэвийн бус байдал” гэдэг нь хүмүүсийн оролт нь гажууд, туршлага нь өрөөсгөл байдаг гэдгийг илтгэдэг.

[3] “Мухардал” гэдэг нь хүмүүсийн явдаг зам Бурханы хүслийн эсрэг байдаг гэсэн үг юм.

ажлын энэ үе шатыг дуусгах үед бүх хүн ердийн хандлагаасаа салж,[4] урт удаан зүүд нойрноосоо сэрнэ. Бурхан нэгэнтээ: “Энэ удаа махбодод ирэх нь барын үүрэнд унахтай адил” гэж хэлж байсныг Би санадаг. Энэ юу гэсэн үг вэ гэхээр Бурханы ажлын энэ шатанд Бурхан махбодод ирж, улмаар агуу улаан лууны оршин суудаг газарт төрсөн учраас энэ удаа газар дээр ирснээрээ Тэр урьдынхаас ч илүү туйлын ноцтой аюултай нүүр тулдаг. Түүний нүүр тулдаг зүйл нь хутга, буу, муна, бороохой; Түүний нүүр тулдаг зүйл нь сорилт; Түүний нүүр тулдаг зүйл нь харгис санаархлаар дүүрсэн зүс царайтай бөөн хүн юм. Тэр хэдийд ч алуулж болох эрсдэлтэй байдаг. Бурхан уур хилэнгээ авч ирсэн. Гэхдээ, Тэр төгс болгох ажлыг хийхийн тулд буюу золин авралын ажлын дараа үргэлжилдэг Өөрийнхөө ажлын хоёр дахь хэсгийг хийхээр ирсэн юм. Ажлынхаа энэ үе шатны төлөө Бурхан бодол, анхаарлаа дээд зэргээр зориулсан ба сорилтын довтолгооноос зайлсхийхийн тулд боломжит бүх аргыг ашиглан, Өөрийгөө даруухнаар нууцалж, Өөрийн ялгамж чанарыг хэзээ ч гайхуулдаггүй. Хүнийг загалмайнаас аврахдаа Есүс золин авралын ажлыг л гүйцэлдүүлсэн; Тэр төгс болгох ажлыг хийгээгүй байв. Тиймээс Бурханы ажлын хагас нь л хийгдсэн бөгөөд золин авралын ажлыг дуусгах нь Түүний бүхий л төлөвлөгөөний ердөө хагас нь байсан юм. Шинэ эрин үе эхэлж, хуучин нь холдон одох гэж байх үед Эцэг Бурхан ажлынхаа хоёр дахь хэсгийг урьдаас төлөвлөж, үүнд бэлдэж эхэлсэн. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон энэ Бурханыг урьд нь тодорхой зөгнөөгүй, тэгснээр энэ удаа махбодод ирсэн Бурханыг тойрсон улам их нууцлаг байдлын суурийг тавьсан. Үүр цайх үед үй олон хүнд мэдэгдэлгүйгээр Бурхан газарт ирж, махбод дахь амьдралаа эхлүүлсэн билээ. Хүмүүс энэ мөч ирснийг ч мэдээгүй. Магадгүй тэд бүгд бөх унтаж байсан, магадгүй сэрүүн сэргэг олон хүн хүлээж байсан, мөн магадгүй олон хүн тэнгэр дэх Бурханд чимээгүйхэн залбирч байсан. Гэсэн ч энэ олон хүний дундаас нэг нь ч Бурхан газар дээр аль хэдийн ирчихсэн гэдгийг мэдээгүй. Өөрийн ажлыг илүү төвөггүй хэрэгжүүлж, илүү сайн үр дүнд хүрэхийн тулд, бас илүү их сорилтоос зайлсхийхийн тулд Бурхан ингэж ажилласан. Хүн хавар цагийн нойрноосоо сэрэх үед Бурханы ажил аль хэдийн дуусчихсан байх ба Тэр явж, газар дэлхий дээр хэрэн хэсэж, түр амьдарсан амьдралаа төгсгөнө. Бурханаас биечлэн ярьж, үйлдэхийг Бурханы ажил шаарддаг учраас, мөн хүн хөндлөнгөөс оролцох ямар ч аргагүй учраас Бурхан газар дээр ирж, Өөрөө ажлаа хийхийн тулд туйлын их зовлон туулсан. Хүн Бурханы ажлыг төлөөлөх чадваргүй. Тиймээс Бурхан Өөрийн ажлыг хийхээр агуу улаан лууны оршин суудаг газар нутагт буун ирэхийн тулд Нигүүлслийн эрин үеийнхээс хэдэн мянга дахин их аюулыг сөрж, овоолсон өтөг баасанд шигдсэн ядуу дорд энэ бүлэг хүмүүсийг золин аврахын тулд бүх бодол санаа, анхаарал халамжаа шавхсан. Бурханы оршин тогтнолыг хэн ч мэддэггүй хэдий ч энэ нь Бурханы ажилд асар их

[4] “Ердийн хандлагаасаа салах” гэдэг нь Бурханыг мэдэж авмагцаа Бурханы талаарх хүмүүсийн үзэл, бодол санаа өөрчлөгддөгийг хэлдэг.

ач тустай учраас Бурханд төвөгтэй байдаггүй. Хүн болгон туйлын жигшмээр, хорон муу байдаг болохоор тэд яаж Бурханы оршин тогтнолыг тэвчих билээ? Тийм учраас, газар дээр ирчхээд Бурхан чимээгүй байдаг. Хүн харгис хэрцгийн туйлшралд автсан ч бай хамаагүй, Бурхан юуг ч хайхардаггүй, харин тэнгэрлэг Эцэгийн Өөрт нь даалгасан илүү агуу даалгаврыг биелүүлэхийн тулд хийх хэрэгтэй ажлаа хийсээр л байдаг. Та нарын дундаас хэн чинь Бурханы хайр татам байдлыг таньж мэдсэн бэ? Эцэг Бурханы ачааг Хүүгээс нь илүү анхаардаг хэн байна вэ? Эцэг Бурханы хүслийг хэн ойлгож чаддаг вэ? Тэнгэр дэх Эцэг Бурханы Сүнс үргэлж түгшиж байдаг ба газар дээрх Хүү нь Эцэг Бурханы хүслийн төлөө байнга залбирч, зүрх сэтгэлээ эмтэртэл санаа зовж байдаг. Хүүгээ хайрладаг Эцэг Бурханы сэтгэлийг мэддэг хүн байна уу? Хайртай Хүү нь Эцэг Бурханаа санадаг сэтгэлийг мэддэг хүн байна уу? Тэнгэр газрын хооронд тусгаарлагдсан энэ хоёр холоос байнга бие биеэ ширтэн, нэг нэгнээ Сүнсээрээ дагаж байдаг. Өө хүн төрөлхтөн! Хэзээ та нар Бурханы зүрх сэтгэлийг анхаарч үзэх юм бэ? Хэзээ та нар Бурханы санаа зорилгыг ойлгох юм бэ? Эцэг Хүү хоёр үргэлж нэг нэгэндээ найдсан. Тэгвэл яагаад Тэд салж, нэг нь дээр тэнгэрт, нөгөө нь доор газарт байх ёстой юм бэ? Хүү нь Эцэгээ хайрладаг шигээр Эцэг нь Хүүгээ хайрладаг. Тэгвэл яагаад Эцэг нь Хүүгээ тийм гүн гүнзгий, шаналгаат хүсэл эрмэлзэлтэйгээр хүлээх ёстой юм бэ? Тэд удаан тусгаарлагдаагүй байж болох ч Эцэг нь хэчнээн олон өдөр шөнийн турш зовж шаналан хүлээн тэмүүлж, хайртай Хүүгээ хурдан эргэж ирэхийг хэр удаан хүлээж байгааг хэн мэдэх билээ? Тэр ажигладаг, чимээгүйхэн суудаг, бас хүлээдэг; хайртай Хүүгээ хурдан ирүүлэхийн төлөө Тэр бүхнийг хийдэг. Газар дэлхийн зах хязгаар луу хэрэн хэссэн Хүүтэйгээ Тэр дахин хэзээ нэгдэх билээ? Эргээд нэгдмэгцээ Тэд үүрд хамт байх хэдий ч нэг нь дээр тэнгэрт, нөгөө нь доор газарт тусдаа байсан олон мянган өдөр шөнийг Тэр яахан тэвчиж чадах билээ? Газар дээрх арван жил тэнгэр дэх мянган жилтэй адилхан санагддаг. Эцэг Бурхан яаж санаа зовохгүй байж чадах юм бэ? Бурхан газар дээр ирээд яг л хүнтэй адилаар хүний ертөнцийн тоймгүй олон нугачааг туулдаг. Бурхан гэм зэмгүй, тэгвэл Тэр яагаад хүнтэй адил зовлон туулах ёстой юм бэ? Эцэг Бурхан Хүүгээ тэсэн ядан хүлээдэгт гайхах юмгүй; Бурханы зүрх сэтгэлийг хэн ойлгож чадах юм бэ? Бурхан хүнд дэндүү ихийг өгсөн; хүн Бурханы зүрх сэтгэлийг хангалттай хариулж яаж чадах билээ? Гэсэн ч хүн Бурханд хэтэрхий багыг өгдөг; тиймээс Бурхан яаж санаа зовохгүй байж чадах юм бэ?

Хүмүүсийн хэв чанар хэтэрхий дорд, сүнс нь нэлээд хөшүүн учраас Бурханы яарсан сэтгэлийг хүмүүсийн дундаас бараг хэн ч ойлгодоггүй тул тэд бүгдээрээ Бурханы хийж байгаа зүйлийг анхаардаг ч үгүй, бас тоодог ч үгүй. Иймээс Бурхан байнга хүний талаар санаа зовж, хүний араатанлаг уг чанар хэзээ мөдгүй гарч ирж болох мэт байдаг. Бурхан газар дээр ирэхэд дэндүү их сорилт дагалддаг гэдгийг үүнээс бүр ч тодорхой харж болно. Гэхдээ бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгохын төлөө алдраар дүүрэн Бурхан, Өөрийн санаа зорилго бүрийг юу ч нуулгүйгээр хүнд

хэлсэн. Тэр энэ бүлэг хүмүүсийг бүрэн төгс болгохоор бат шийдсэн тул ямар ч бэрхшээл сорилт тулгарсан бай, харц буруулан энэ бүхнийг үл тоодог. Тэр зөвхөн чимээгүйхнээр Өөрийн ажлыг хийж, нэг л өдөр Бурхан Өөрийн алдрыг олж авах үед хүн Өөрийг нь мэднэ гэдэгт бат итгэдэг бөгөөд хүн Бурханаар бүрэн төгс болгуулмагцаа Бурханы зүрх сэтгэлийг бүрэн ойлгоно гэж итгэдэг. Яг одоо хүмүүс Бурханыг сорьж, Бурханыг буруу ойлгож, эсвэл Бурханыг буруутгаж байж магадгүй; Бурхан эдгээрийн алийг ч хайхардаггүй. Бурхан алдар руу буун ирэх үед хүмүүс, Бурханы хийдэг бүхэн хүн төрөлхтний аз жаргалын төлөө байдаг гэдгийг бүгдээрээ ойлгож, Бурханы хийдэг бүхэн хүн төрөлхтнийг илүү сайхан амьдруулахын төлөө байдаг гэдгийг ойлгоно. Бурхан ирэхдээ сорилт авчирдаг, Тэр ирэхдээ бас сүр жавхлан, уур хилэнг авчирдаг. Бурхан хүнийг орхих үедээ аль хэдийн Өөрийн алдрыг олчихсон байдаг бөгөөд алдар суугаар дүүрч, буцахын баяр хөөртэйгээр явж оддог. Газар дээр ажилладаг Бурхан хүмүүс Өөрийг нь хэчнээн голсон ч бай, үүнийг хайхардаггүй. Тэр зүгээр л Өөрийн ажлыг хийсээр байдаг. Бурхан дэлхий ертөнцийг олон мянган жилийн өмнө бүтээсэн, Тэрээр хэмжээлшгүй их ажил хийхийн тулд газар дээр ирсэн бөгөөд хүний ертөнцийн гололт, гүжирдлэгийг бүрэн туулсан юм. Бурханыг ирэхэд хэн ч угтан авдаггүй; Түүнтэй хүйтэн хөндий мэндэлдэг. Бэрхшээл зовлонгоор дүүрэн энэ хэдэн мянган жилийн хугацаанд, хүний биеэ авч явах байдал хэдийнээ Бурханы зүрх сэтгэлийг шархлуулжээ. Тэрээр хүмүүсийн дуулгаваргүй байдалд анхаарал хандуулахаа больж, харин ч хүнийг өөрчилж, ариусгахын тулд өөр нэг төлөвлөгөө боловсруулсан. Тохуурхал, гүжирдлэг, хавчлага, гай зовлон, цовдлолын зовлон, хүмүүсийн мөрдлөг гэх зэргийг Бурхан махбодод ирснээсээ хойш амссан: Бурхан эдгээр зүйлийг хангалттай амталсан бөгөөд хүний ертөнцийн бэрхшээлийн тухайд бол махбодод ирсэн Бурхан энэ бүхнийг бүхэлд нь амссан билээ. Тэнгэр дэх Эцэг Бурханы Сүнс тийм төрх байдлыг аль хэдийн харж тэвчихээ болиод, толгойгоо гэдийлгэн, нүдээ аньж, хайртай Хүүгээ эргэн ирэхийг хүлээдэг. Тэгээд хүмүүс сонсож, дуулгавартай дагаж, Түүний махан биеийн өмнө туйлын их ичиж, Түүний эсрэг тэрслэхээ болиосой гэж л Тэр хүсдэг. Хүмүүс Бурханы оршин тогтнолд итгэж чадаасай гэж л Тэр хүсдэг. Хүнээс их зүйл шаардахаа Тэр аль хэдийн больсон, учир нь Бурхан хэтэрхий өндөр төлөөс төлсөн атал хүн тайван амарч,[5] Бурханы ажлыг огтхон ч хайхардаггүй.

Бурханы ажлын талаар өнөөдөр ярьж байгаа зүйл минь ихээхэн “утгагүй зүйл”[6] агуулж байж магадгүй, гэсэн хэдий ч энэ нь хүний оролттой гүн гүнзгий хамаатай. Би зүгээр л ажлын талаар бага зэрэг, дараа нь оролтын талаар бага зэрэг ярьж байгаа боловч энэ хоёр тал адилхан чухал бөгөөд эдгээрийг нэгтгэвэл хүний аминд

[5] “Тайван амарч” гэдэг нь хүмүүс Бурханы ажлын талаар анхаардаггүй, чухал гэж үздэггүй гэсэн үг юм.

[6] “Утгагүй зүйл” гэдэг нь хүмүүс үндсэндээ Бурханы хэлдэг үгийн үндсийг ойлгох чадваргүй байдаг ба Түүний ярьж байгаа зүйлийг огт мэддэггүй гэсэн үг юм. Энэ хэллэгийг егөөдөн ашигласан.

бүр ч их ач тустай. Энэ хоёр тал нь бие биеэ нөхдөг,[7] асар их ач тустай бөгөөд хүмүүст Бурханы хүслийг улам сайн ойлгуулж, Бурхан болон хүмүүсийг харилцах боломжтой болгодог. Ажлын талаарх өнөөдрийн яриагаар дамжуулан Бурхантай харилцах хүмүүсийн харилцаа улам сайжирч, харилцан ойлголцол нь гүнзгийрч, хүн Бурханы ачааг илүү их анхаарч, хайхарч чаддаг; хүн Бурханы мэдэрдэг зүйлийг мэдэрч, Бурхан өөрийг нь өөрчилнө гэдэгт илүү их итгэлтэй болж, Бурханы дахин илрэлтийг хүлээдэг. Энэ бол өнөөдөр хүнээс Бурханы шаарддаг цорын ганц шаардлага—Бурханыг хайрладаг нэгний дүрийг амьдран харуулж, улмаар Бурханы мэргэн ухааны биелэлтийн гэрлийг харанхуйн эрин үед гялбуулах явдал бөгөөд ингэснээр хүний амьдран харуулдаг зүйл Бурханы ажилд гялалзсан хуудсыг үлдээж, ертөнцийн Зүүн зүгт мөнхөд гэрэлтэж, дэлхий ертөнцийн анхаарал, бүх хүний бишрэлийг төрүүлж болох юм. Энэ нь өнөө үед Бурханыг хайрладаг хүмүүсийн хувьд бүр ч сайн оролт гэдэг нь эргэлзээгүй.

АЖИЛ БА ОРОЛТ 5

Өнөө үед хүн нэг бүрийг эрх чөлөөт ертөнцөд амьдруулахын тулд Бурхан хүмүүсийг амьдралын зөв замнал руу хөтөлж, өөр эрин үе рүү дараагийн алхмаа хийхэд нь чиглүүлж, энэхүү харанхуй хуучин эрин үе, махан биеийг даван гарч, харанхуйн хүчний дарлал, Сатаны нөлөөнөөс ангижрахад нь удирдан чиглүүлж байгааг та нар бүгд мэднэ. Сайн сайхан маргаашийн төлөө, маргааш хүмүүс илүү зоригтой алхам хийгээсэй гэсэндээ Бурханы Сүнс хүний төлөө бүх зүйлийг төлөвлөдөг бөгөөд хүн улам их баясалтай байг гэж Бурхан махбодоор бүх хүчин чармайлтаа гарган хүний өмнөх замыг бэлтгэж, хүний хүсэн мөрөөсдөг өдрийг наашлуулдаг. Ийм сайхан мөчийг та бүгд нандигнадаг ч болоосой; Бурхантай уулзана гэдэг амаргүй хэрэг. Бурханыг огт мэддэггүй байсан ч Түүнтэй чи эртнээс хамт байж ирсэн. Сайхан атлаа зуурдын энэ өдрүүдийг хүн бүр үүрд санан дурсаж, газар дэлхий дээрх нандин өмчөө болгож чаддаг ч болоосой. Бурханы ажил аль эрт хүнд илчлэгдсэн—гэвч хүмүүсийн зүрх сэтгэл хэтэрхий ээдрээтэй, мөн хүмүүс огт сонирхдоггүй байснаас үүдэн Бурханы ажил анхдагч суурин дээрээ завсарласан хэвээр үлджээ. Хүмүүсийн бодол, үзэл, сэтгэлгээ хоцрогдмол хэвээр байгаа мэт санагдах бөгөөд олонхынх нь сэтгэх өнцөг бүр эрт үеийн балар эртний хүнийхтэй адил, өчүүхэн ч өөрчлөгдөөгүй. Иймээс хүмүүс Бурханы хийдэг ажлыг гайхаж, тодорхой мэдэхгүй хэвээр байдаг. Өөрсдийн хийдэг зүйл, орох ёстой зүйлийн талаар тэд бүр ч мэддэггүй. Эдгээр нь Бурханы ажилд асар их бэрхшээл учруулж, хүмүүсийн амь ахин дэвшихэд ямагт саад хийдэг. Хүний мөн чанар, дорд муу хэв чанараас үүдэн хүмүүс үндсэндээ Бурханы ажлыг ухаарах чадваргүй

[7] “Бие биеэ нөхдөг” гэдэг нь хэрвээ “ажил” болон “оролтыг” хоёуланг нь нөхөрлөлөөр нэгтгэвэл Бурханы талаарх бидний мэдлэгт бүр ч их ач тустай байна гэсэн үг юм.

байдаг бөгөөд эдгээр зүйлийг хэзээ ч чухалчилж авч үздэггүй. Та нар амиа өсгөхийг хүсвэл оршин тогтнолынхоо нарийн ширийнд анхаарал хандуулан, амийн оролтоо хянах, дор бүрнээ зүрх сэтгэлээ бүрмөсөн өөрчлөх, сэтгэл дэх хоосрол, өөрсдийг чинь зовоодог улиг болсон, уйтгартай оршин тогтнолын асуудлыг шийдвэрлэхийн тулд тэдгээрийг нэг бүрчлэн ухаарах ёстой. Ингэснээр та нар дор бүрнээ гадна доторгүй шинэчлэгдэн, өсөн нэмэгдсэн, ер бусын, эрх чөлөөт амьдралыг үнэхээр эдлэх болно. Энэ нь та нарыг дор бүрд чинь амилуулж, сүнсийг чинь сэргээж, амьд зүйлийн төрхийг эзэмшүүлэх зорилготой. Уулзсан бүх ах эгчийн чинь дунд цовоо, сэргэг хүн бараг байдаггүй. Тэд бүгд ухаан мөхөс, мунхаг, харваас хөгжих ямар ч боломжгүй эртний бичин хүн шиг байдаг. Үүнээс ч долоон дор нь, Миний уулзсан ах эгч нар уулын зэрлэгүүд шиг бүдүүлэг, соёлгүй байлаа. Тэд боловсон байдлын талаар бараг юу ч мэддэггүй, биеэ авч явах суурь ойлголтыг бүр ч мэддэггүй. Ухаалаг, төлөв төвшин харагддаг, цэцэг шиг хөөрхөн өсөж торнисон атлаа “этгээд” загвараар хувцасладаг залуу эгч олон бий. Нэг эгчийн[a] үс нүүрийг нь бүрэн халхлаад, хоёр нүд нь огт харагддаггүй. Нүүрнийх нь хэлбэр цэвэрхэн, буянтай боловч үснийх нь загвар ой гутам бөгөөд хүүхдийн цагдан хорих төвийн хамгийн хүнд хэрэгтэн байсан мэт хачин мэдрэмж төрүүлдэг. Усанд байгаа маргад эрдэнэ мэт тунгалаг, цогтой нүд нь хувцаслалт, үс засалтад дарагдаад түнэр харанхуй шөнө гэнэт үзэгдэн нүд гялбуулам тодоор анивчин цацарч, хүмүүний зүрхэнд айдас хуруулдаг хос дэнлүү мэт байхын зэрэгцээ хэн нэгнээс тэр эгч албаар нуугдаж байгаа мэт харагддаг. Надтай уулзах үедээ тэр эгч саяхан хүн хөнөөчихсөн алуурчин мэт “хэргийн газраас” зугтах арга ямагт сэдэх агаад баригдахаас ихэд айн цаг үргэлж булзаж байдаг; мөн олон үеэрээ боол явсан, бусдын өмнө хэзээ ч толгойгоо өргөж чаддаггүй Африкийн хар арьстан[1] мэт аашилдаг. Энэ хүмүүсийн хувцаслаж, биеэ арчилдаг арга хүртэлх ийм хүрээний зан авирыг сайжруулахад олон сарын ажил орно.

Олон мянган жилийн туршид хятад хүмүүс боолын амьдралаар амьдарч ирсэн нь тэдний бодол, үзэл, амьдрал, хэл яриа, ааш авир, үйлдлийг маш их хязгаарлан, өчүүхэн төдий ч эрх чөлөө үлдээгээгүй юм. Хэдэн мянган жилийн түүх сүнстэй амьд хүмүүсийг аваад сүнсгүй хүүр мэт болгон доройтуулжээ. Сатаны зандалчны хутган дор амьдардаг хүмүүс олон, араатны үүр шиг гэрт амьдардаг хүмүүс олон, адуу үхрийнх шиг хоол идэж, “нөгөө ертөнцөд” ухаан мэдрэлгүй, замбараагүй хэвтээ хүмүүс олон. Гаднах дүрээрээ хүмүүс балар эртний хүнээс ялгаагүй, амрах газар нь там мэт бөгөөд элдэв янзын бузар чөтгөр, муу ёрын сүнсээр хүрээлүүлэн, тэдэнтэй нөхөцдөг. Гаднаа хүн дээд “амьтан” мэт харагддаг ч үнэндээ бузар чөтгөрүүдтэй амьдарч, оршин суудаг. Асарч халамжлах нэгэнгүй хүмүүс Сатаны

[a] Эх бичвэрт “Түүний” гэж байдаг.

[1] “Африкийн хар арьстан” гэдэг нь Бурханаар хараагдан үеэс үед боолчлуулж ирсэн хар арьст хүмүүсийг хэлдэг.

занган дотор хүнд хөдөлмөрт баригдан зугтах аргагүй амьдардаг. Хүмүүс тухлаг гэрт хайртай хүмүүсээ цуглуулаад аз жаргалтай, сэтгэл хангалуун амьдралаар амьдардаг гэхээсээ илүүтэй хүн төрөлхтөн чөтгөрүүдтэй харьцаж, диаволуудтай холбогдон Үхэгсдийн оронд амьдардаг гэж хэлэх нь зүйтэй. Үнэн хэрэгтээ хүмүүс мөн л Сатанд хүлүүлэн, бузар чөтгөрүүдийн цугладаг газарт амьдарч, тэдний ор дэр өөрсдийнх нь цогцсоо нойрсуулах газар мэт, тав тухтай үүр мэт байцгаан, энэхүү бузар чөтгөрүүдийн явуулгад автдаг. Гэрт нь ороход хашаа нь хүйтэн, эл хуль агаад жихүүн салхи хуурай мөчир дундуур исгэрнэ. “Амьдардаг өрөөнийх” нь хаалгыг нээхэд өрөө нь тас харанхуй—гараа сунгавал хуруу харагдахааргүй. Хаалганы завсраар багахан гэрэл тусах нь өрөөг улам ч дүнсгэр, аймшигтай санагдуулна. Хаяа нэг хархнууд хачин жигтэйгээр час хийх нь баяр наадам хийж буй мэт. Дөнгөж сая авсанд орсон хүний амьдарч асан гэр шиг өрөөн дэх бүхэн ой гутам, айдас хүргэм. Өрөөн дэх ор хөнжил, нүд булаах юмгүй жижигхэн шүүгээ бүгд тоосонд дарагдаж, газар дээр хэдэн бяцхан сандал шүдээ ярзайлган хумсаа ярах бөгөөд ханан дээр аалзны тор унжина. Ширээн дээр толь, хажууд нь модон сам тавиатай. Толь руу алхаж очоод лаа авч асаалаа. Толийг тоос бүрхсэн харагдах нь хүмүүсийн тусгал[б] дээр нэг ёсны “энгэсэг” үүсгэж, саяхан булшнаас босоод ирсэн мэт харагдуулна. Сам нь үсээр дүүрэн. Энэ бүх зүйл хуучин, эв хавгүй агаад дөнгөж нас барсан хүн хэрэглэж байсан мэт санагдана. Сам руу харахад, хажууд нь цогцос тавьсан байж магадгүй санагдана. Саман дахь үс эргэлдэх цусгүй тул үхэгсдийн үнэр ханхлуулна. Жихүүн салхи хаалганы завсраар сийгэх нь тэр завсраар сүнс шурган орж, өрөөнд амьдрахаар эргэн ирж буй мэт. Өрөөнд тэсэхийн аргагүй жихүүдэс мэдрэгдэн, илжирч буй хүүр мэт өмхий гэнэт ханхалж, энэ агшинд хана дээр замбараагүй олон зүйл өлгөөтэй харагдан, орон дээр хиртэй, үнэр орсон замбараагүй даавуу, буланд үр тариа байх бөгөөд шүүгээ нь тоосонд дарагдаатай, шал нь мөчир, хир буртагт бүрхээтэй—үхсэн хүн шүдээ хавирч, агаар луу сарвайн, дөнгөж саяхан эдгээрийг хэрэглэсэн мэт. Энэ нь хангалттай жихүүдэс төрүүлнэ. Өрөөний хаана ч амьдралын өчүүхэн ч шинж тэмдэггүй, Бурханы ярьсан Үхэгсдийн орон, там адил бүгд харанхуй, чийглэг. Гашуудлын хувцас өмсөөд үхэгсдэд чимээгүйхэн хүндэтгэл үзүүлж буй будаггүй шүүгээ, сандал, цонхны хүрээ, хаалга яг л хүний булш адил. Хүн эрт гараад оройтож ирэн энэхүү нөгөө ертөнцөд олон арав, зуу, олон мянган жил амьдарсаар байна. Үүрийн гэгээгээр азарган тахиа донгодох үед тэд “булшнаасаа” гараад тэнгэр өөд харж, газар луу зэрвэс шагайчхаад өдрийн ажлаа эхэлдэг. Нар уулын цаагуур жаргах үед ядарсан биеэ “булш руугаа” чирч авчирдаг; гэдсээ дүүргэх үед нь харуй бүрий болдог. Дараа нь маргааш “булшнаасаа” гарах бэлтгэлээ хийж дуусаад сүүмэлзэх галын дөлөөс цацарч буй мэт санагдах гэрлээ унтраадаг. Энэ үед сарны гэрэл дор булшны хиргисүүр намхан толгод мэтээр өнцөг булан бүрд түгж байгаа нь харагдана.

[б] Эх бичвэрт “хүмүүсийн царай” гэж байдаг.

“Булшин” дотроос хаяа нэг хурхирах дуу их багаар гарна. Хүмүүс бүгд дуг нойрондоо дугжирч, бузар чөтгөр, сүнснүүд ч бүгд тайван амарч буй мэт санагдана. Хэрээ алсад гуаглах нь хаяа нэг сонстох бөгөөд анир чимээгүй, нам гүм шөнөөр ийм гаслант эр чимээнд ар нуруугаар аргагүй хүйт дааж, шар үс босно… Хүн үхэж, дахин төрсөөр ийм орчинд хэчнээн жилийг үдсэнийг хэн мэдэх билээ; хүмүүс сүнстэй нөхцөх хүний ертөнцөд хэр удаан байсныг нь хэн мэдэх билээ, түүнчлэн хэчнээн удаа энэ ертөнцтэй салах ёс гүйцэтгэснийг нь хэн мэдэх билээ. Хүмүүс Үхэгсдийн орны амьдралд аль эрт дассан тул газар дээрх энэ тамд гомдлын ганц ч үггүй мэт аз жаргалтай амьдардаг. Иймээс хүмүүс бузар чөтгөрүүд өөрсдийнх нь найз, нөхөр мэт, хүний ертөнц гэдэг дээрэмчдийн бүлэг[2] мэтээр бузар чөтгөрүүдийн оршин суудаг энэ газрыг сониучирхдаг—учир нь хүний анхдагч мөн чанар аль хэдийн аниргүйгээр алга болж, ул мөргүй арилсан ажгуу. Хүмүүсийн дүр төрх бузар чөтгөрийнх гэмээр; гол нь тэдний үйлдлийг бузар чөтгөрүүд удирддаг. Өнөөдөр хүмүүс бузар чөтгөрөөс төрсөн мэт бузар чөтгөрөөс ялгаагүй харагддаг. Түүнчлэн өвөг дээдсээ туйлын их хайрлаж, дэмждэг. Сатан хүнийг нухалсаар аль эрт уулын бич шиг болгосон гэдгийг хэн ч мэддэггүй. Улайсан нүд нь царайчилсан харцтай, цацруулдаг бүдэг гэрэл нь бузар чөтгөрийн хөнөөлт хорон санааны үл ялиг шинжтэй. Царай нь нарсны хагарсан холтос мэт үрчлээнд бүрхэгдэж, ам нь Сатанаар загварчлуулсан мэт урагш цорвойн, чих нь гадна доторгүй хирээр бүрхэгдэж, нуруу нь бөгтийж, хөл нь биеэ дийлж ядан, ясархаг гар нь нэгэн хэмээр нааш цааш савлана. Тэд яс арьснаас цаашгүй болсон атлаа бас уулын баавгай шиг тарга тэвээрэгтэй. Тэгээд тэр чигтээ балар эртний бич адил арчилгаа, хувцаслалттай—өнөөдөр эдгээр бич орчин цагийн хүний хэлбэр лүү бүрэн хувьсах[3] болоогүй мэт, үнэхээр хоцрогдмол байдаг!

Хүмүүс амьтадтай зэрэгцэн амьдарч, зөрчил, хэл ам гаргалгүй эв найртай байдаг. Хүн амьтдыг хянуур анхаарч, харж ханддаг бөгөөд амьтад өөрсдөө ямар ч ашиг хүртэлгүйгээр хүнийг амьд байлгахын төлөө, харваас тэдний ашиг тусын тулд хүнд бүрэн дуулгавартай оршин тогтнодог. Хаанаас нь ч харлаа гэсэн хүн, адгуус хоёрын харилцаа ойр дотно,[4] эв эетэй,[5] харин бузар чөтгөрүүд бол хүн, адгуусны төгс хослол мэт санагдана. Иймээс хүмүүс газар дээрх бузар чөтгөрүүдтэй бүр ч дотно, салж хагацашгүй байдаг: Хүн бузар чөтгөрүүдээс хол байхдаа ч тэдэнтэй холбоотой үлддэг; харин бузар чөтгөрүүд хүнээс юугаа ч харамлалгүй, байгаа бүхнээ тэдэнд “зориулдаг”. Хүмүүс өдөр бүр “тамын хааны ордонд” наадаж,

---

[2] “Дээрэмчдийн бүлэг” нь хүн төрөлхтний завхралыг болон хүн төрөлхтний дунд нэг ч ариун хүн байхгүй байгааг хэлдэг.

[3] “Хувьсах” гэдэг нь бичин хүн өнөөгийн хүний хэлбэр лүү “хувьсахыг” хэлдэг. Энэ нь, егөөдсөн санаатай: Балар эртний бич цэх алхдаг хүн болж хувирсан хэмээх тийм онол үнэн хэрэгтээ байхгүй билээ.

[4] “Ойр дотно” гэдгийг егөөдсөн байдлаар хэрэглэжээ.

[5] “Эв эетэй” гэдгийг егөөдсөн байдлаар хэрэглэжээ.

(өөрсдийн өвөг дээдэс болох) “тамын хааны” хамтаар үсрэн дэвхцэж, явуулгад нь автаж байдаг тул өнөөдөр хүмүүс хир буртагт баригдсан бөгөөд Үхэгсдийн оронд нэлээд хугацааг өнгөрүүлснийхээ дараа “амьдын ертөнцөд” эргэн ирье гэж хүсэхээ аль эрт больжээ. Иймээс тэд гэрэл харж, Бурханы шаардлага, зан араншин, ажлыг үзмэгцээ сэтгэл нь үймэрч санаа зовон, нөгөө ертөнц рүү буцаж, сүнснүүдтэй хамт амьдрахыг мөрөөссөөр байдаг. Тэд аль эрт Бурханыг мартсан тул цаг ямагт үхээрийн газраар тэнүүчилж иржээ. Би хүнтэй уулзаад ярилцах гэж оролддог бөгөөд өмнө минь зогсоо хүн бол хүн огт биш гэдгийг тэр үед л олж мэддэг. Үс нь арзайж, царай нь халтартсан түүний ярзайсан инээмсэглэлд чонын гэмээр зүйл байдаг. Мөн тэр булшнаас дөнгөж гарч ирээд амьдын ертөнцийн хүн харсан сүнс шиг эв хавгүй санагддаг. Энэ хүн үргэлж инээмсэглэх гэж хичээдэг нь дотуур тамиртай төдийгүй ёрын харагддаг. Хэлэх зүйл байгаа ч юу гэж хэлэхээ мэдэхгүй байгаа тул нэг тийш зогсон, нүүрний хувиралгүй, тэнэг царайлахаас өөр аргагүй байгаа мэтээр Над руу инээмсэглэдэг. Араас нь харахад “хөдөлмөрч хятад хүмүүсийн сүрлэг дүртэй” харагдах тэр бүсгүй ийм мөчүүдэд улам зэвүүн харагдаж, хүмүүсийн хэлдгээр дээр үеийн домогт Янь Хуан/Янь Ваны[в] үр удмын дүрийг санагдуулдаг. Намайг юм асуухад тэр чимээгүйхэн толгой гудайлгана. Удаж байж хариулах бөгөөд хариулт нь тун итгэлгүй. Гараа зүгээр байлгаж чадалгүй хоёр хуруугаа муур шиг хөхнө. Цагаан байх ёстой гэж хэзээ ч мэдэгдэхээргүй өнгөө алдсан хугархай хумстай, “нарийхан” хумс нь зузаан хиртэй болсон хүний гар дөнгөж саяхан хог ухаж байсан гэлтэй харагддагийг Би одоо л ухаарч байна. Гарынх нь ар тал өдөө дөнгөж зулгаалгасан тахианы арьс шиг харагдах нь бүр ч ой гутмаар. Алган дээрх зурааснууд нь бараг бүгд хүний хөдөлмөрийн хөлс, цусны үнийг шингээсэн байх бөгөөд хүний зовлонт сүнсний нандин, магтууштай байдлыг харуулахын тулд дор бүрнээ хир шиг зүйл агуулж, “хөрс шорооны үнэр” ялгаруулах мэт болдог—ингэснээр энэхүү зовлонт сүнс хүртэл хүний гарын алганы зураас бүрд гүнээ нэвчсэн байдаг. Хүний хөлөөсөө толгой хүртэл өмсдөг аль ч хувцас ангийн үс шиг харагддаггүй, гэвч хувцас нь тэднийг аль эртнээс маш муухай болгон, гахай нохойноос ч долоон дор харагдуулах болсон тул тэд хэчнээн их “хүндтэй” ч үнэндээ үнэгний үснээс дор, бүр тогосын ганц өднөөс ч бага үнэ цэнтэй байдгаа ер мэддэггүй. Тэр бүсгүйн богинохон цамц нурууных нь хагаст унжиж, тахианы гэдэс дотор шиг өмднийх нь түрий үзэшгүй муухайг нь нарны хурц гэрэлд бүрэн илчилдэг. Хоёр хөл нь боолгоогүй удсан, хуучин нийгмийн “гурван ямхын алтан лянхуа” байхаа больсон гэдгийг харуулах гэсэн мэтээр түрий нь богинохон, нарийн байдаг. Энэ хүний хувцас хэт баруунжсан, ил задгай. Уулзах үед тэр үргэлж бишүүрхэж, нүүр нь улаа бутарч, бузар чөтгөрүүдэд дэвслүүлсэн аятай толгойгоо эгцэлж огт

[в] “Янь”, “Хуан” гэдэг нь Хятадын соёлын үрийг эхлэн таригчдад багтдаг домгийн хоёр хааны нэрс юм. “Янь Ван” нь “тамын хаан” гэсэн хятад нэр бөгөөд мандаринаар “Янь Хуан”, “Янь Ван” нь бараг адилхан сонсогддог.

чаддаггүй, мөн хүмүүсийг эгцлэн харж зүрхлэхгүй болсон байдаг. Хүний царай тоосонд дарагддаг. Тэнгэрээс унасан энэ тоос бүгдээрээ хүний нүүрэн дээр шударга бусаар унах мэт болж, хүний царайг бор шувууны өд шиг харагдуулдаг. Хүний нүд ч бор шувууных шиг жижигхэн, онцлох зүйлгүй, ямар ч цог золбоогүй. Ярилцах үедээ хүмүүс зуршсан ёсоороо яриагаа түгдрүүлж, булзааруулах нь бусдад зэвүүцэм, ой гутам байдаг. Гэвч ийм хүмүүсийг олон түмэн “улс үндэстний төлөөлөл” гэж магтдаг. Энэ нь хөгийн хэрэг бус уу? Бурхан хүмүүсийг өөрчилж, аварч, үхлийн булшнаас гаргаж, Үхэгсдийн орон, там дахь амьдралаас нь ангижруулахыг хүсдэг билээ.

АЖИЛ БА ОРОЛТ 6

Ажил болон оролт нь угаасаа бодитой байдаг; тэдгээр нь Бурханы ажил болон хүний оролтыг хэлдэг. Бурханы жинхэнэ нүүр царай болон Бурханы ажлыг хүн ойлгож огт чаддаггүй нь түүний оролтод хамгийн их бэрхшээл авчирсан. Бурхан эцсийн өдрүүдэд ямар ажил хийхийг, эсвэл махбодод ирж, сайн муугийн алинд ч хүнтэй хамт зогсохын тулд Бурхан яагаад туйлын их доромжлол амссан болохыг өнөөдөр ч гэсэн олон хүн мөн л мэддэггүй. Бурханы ажлын зорилгоос эхлээд эцсийн өдрүүдэд зориулсан Бурханы төлөвлөгөөний зорилго хүртэлх эдгээр зүйлийг хүмүүс ер мэддэггүй. Олон янзын шалтгаанаар хүмүүс Бурханы шаарддаг оролтын тухайд үргэлж хайнга, хоёрдмол санаатай[1] байсаар ирсэн нь махбод дахь Бурханы ажилд туйлын их бэрхшээл авчирсан юм. Хүмүүс бүгд саад тотгор болсон мэт санагддаг ба өнөөдөр ч гэсэн тэд тодорхой ойлгохгүй хэвээр байдаг. Тийм учраас, та нарыг Иов шиг, Бурханыг голсноос үхэхийг илүүд үзэн, бүхий л доромжлолыг тэвчих Бурханы үнэнч зарц болгохын тулд, мөн Петр шиг бүхий л оршихуйгаа Бурханд өргөж, эцсийн өдрүүдэд Бурханаар авхуулах дотнын хүмүүс болгохын тулд бид хүн дээр хийдэг Бурханы ажил, Бурханы яаралтай санаа зорилгын талаар ярих ёстой гэж Би бодож байна. Бүх ах эгч нар байгаа бүхнээ өгч, өөрсдийн бүхий л оршихуйг Бурханы тэнгэрлэг хүсэлд өргөн барьж, Бурханы гэр дэх ариун зарц болж, Бурханы хайрласан хязгааргүй их амлалтыг эдэлж, ингэснээр Эцэг Бурханы зүрх сэтгэл тун удалгүй тайван амрах болтугай. “Эцэг Бурханы хүслийг биелүүлэх” гэдэг нь Бурханыг хайрладаг бүх хүний уриа байх ёстой. Эдгээр үг хүний оролтын хөтөч, түүний үйлдлүүдийг чиглүүлэх луужин болох ёстой. Энэ нь хүнд байх ёстой шийдвэр мөн. Газар дээрх Бурханы ажлыг бүрэн гүйцэлдүүлж, махбод дахь Бурханы ажилтай хамтран ажиллах нь хүний үүрэг бөгөөд нэг л өдөр Бурханы ажил дуусах үед Түүнийг тэнгэр дэх Эцэг рүүгээ эртхэн буцан очиход хүн баяртайгаар уднэ. Энэ нь хүний биелүүлэх ёстой хариуцлага биш гэж үү?

[1] “Хоёрдмол санаатай” гэдэг нь Бурханы ажлын талаарх тодорхой мэдлэг ухаан хүмүүст байдаггүй гэдгийг илтгэдэг.

Нигүүлслийн эрин үед Бурхан гуравдагч тэнгэр лүү буцахад бүх хүн төрөлхтнийг золин аврах Бурханы ажил үнэндээ аль хэдийн сүүлчийн хэсэг рүүгээ шилжсэн. Газар дээр үлдсэн бүхэн нь Есүсийн нуруундаа үүрсэн загалмай, Есүсийг ороосон нарийн маалинга, Есүсийн өмссөн өргөст титэм, час улаан нөмрөг байлаа (эдгээр нь Түүнийг дооглохын тулд иудейчүүдийн ашигласан эд юмс байв). Өөрөөр хэлбэл, Есүсийн цовдлолын ажил асар их шуугиан тарьсны дараа юмс дахин намжжээ. Тэр үеэс эхлээд Есүсийн шавь нар Түүний ажлыг үргэлжлүүлж, хаа сайгүй байсан чуулганuудыг хариулж, усалж эхэлсэн юм. Тэдний ажлын агуулга нь дараах байдалтай байв: Тэд бүх хүнээс гэмшиж, нүглээ улайж, баптисм хүртэхийг шаардсан; элчүүд бүгд Есүсийн цовдлолын дотоод түүх, нэмж хачирлаагүй үнэн болон Есүсийн цовдлолын тухай түгээхээр явсан тул хүн бүр Есүсийн өмнө нүүрээрээ газар унан мөргөж нүглээ улайхаас өөр аргагүй болжээ; түүнчлэн, элчүүд Есүсийн хэлсэн үгийг хаа сайгүй тунхаглахаар явсан билээ. Тэр үеэс Нигүүлслийн эрин үеийн чуулганuудыг байгуулж эхэлсэн юм. Тухайн эрин үед Есүсийн хийсэн зүйл ч бас хүний амьдрал болон тэнгэрлэг Эцэгийн хүслийн тухай л ярих явдал байсан бөгөөд эрин үе өөр байсан учраас тэдгээр үг болон хэрэгжүүлэлтийн олонх нь өнөөдрийнхөөс асар их ялгаатай байлаа. Гэхдээ мөн чанартаа тэдгээр нь адилхан: Яг нарийндаа хоёулаа л махбод дахь Бурханы Сүнсний ажил юм. Ийм ажил болон айлдвар өнөөг хүртэл үргэлжилсэн тул өнөөдрийн шашны байгууллагууд иймэрхүү зүйлийг өөр хоорондоо хуваалцсаар байгаа бөгөөд энэ нь огт өөрчлөгддөггүй. Есүсийн ажил дуусаж, чуулганууд Есүс Христийн зөв замд аль хэдийн орсон боловч Бурхан ажлынхаа өөр нэг үе шатны төлөвлөгөөг эхлүүлсэн нь эцсийн өдрүүдэд махбодод ирэх явдал байв. Хүний харж байгаагаар, Бурханы цовдлол нь бие махбодтой болсон Бурханы ажлыг аль хэдийн төгсгөж, бүх хүн төрөлхтнийг золин аварч, Үхэгсдийн орны түлхүүрийг авах боломжийг Бурханд олгосон. Хүн бүр Бурханы ажил бүрэн гүйцэлдсэн гэж боддог. Үнэн хэрэгтээ, Бурханы өнцгөөс бол Түүний ажлын жаахан хэсэг л гүйцэлдсэн юм. Тэрээр хүн төрөлхтнийг л золин аварсан; харин хүн төрөлхтнийг байлдан дагуулаагүй, хүний сатанлаг төрхийг бүр ч өөрчлөөгүй. Тийм учраас Бурхан “Миний махбод болсон бие үхлийн шаналлыг туулсан хэдий ч тэр нь бие махбодтой болсны минь бүхий л зорилго байгаагүй. Есүс бол Миний хайртай Хүү бөгөөд Миний төлөө загалмайд цовдлогдсон боловч Миний ажлыг бүрэн дуусгаагүй. Харин нэг хэсгийг нь л хийсэн юм” хэмээн хэлдэг. Тиймээс Бурхан бие махбодтой болох ажлыг үргэлжлүүлэх төлөвлөгөөнийхөө хоёр дахь үеийг эхлүүлсэн. Бурханы туйлын зорилго нь Сатаны савраас аврагдсан бүх хүнийг төгс болгож, олж авах явдал учраас махбодод ирэхийн аюулыг дахин нэг удаа сөрөхөөр Бурхан бэлдсэн билээ. “Бие махбодтой болох” гэдэг нь алдар суу авчирдаггүй (Бурханы ажил хараахан дуусаагүй учраас) боловч хайртай Хүүгийн ялгамж чанартайгаар гарч ирдэг Нэгнийг хэлдэг, Тэр бол Христ, Бурханы таалал Түүнд оршдог гэсэн үг юм. Тийм учраас, үүнийг “аюулыг сөрөх” гэж хэлдэг. Бурханы махбод болсон бие хүч

чадал багатай, асар болгоомжтой байх ёстой[2] бөгөөд Түүний хүч чадал тэнгэр дэх Эцэгийн эрх мэдлээс асар зөрүүтэй; Тэрээр махбодын үйлчлэлийг л хэрэгжүүлэн, өөр ажилд оролцолгүйгээр Эцэг Бурханы ажил болон даалгаврыг биелүүлж, ажлын нэг хэсгийг л гүйцэтгэдэг. Ийм учраас Бурханыг газар дээр ирмэгц нь “Христ” гэж нэрлэсэн. Энэ нь уг нэрд агуулагдсан утга учир юм. Ирэхэд нь сорилт дагалддаг гэж хэлдгийн учир нь ажлын нэг хэсэг л биелж байгаагаас болдог. Түүнчлэн, Эцэг Бурхан Түүнийг зөвхөн “Христ”, “хайртай Хүү” хэмээн дууддаг ч Түүнд бүх алдрыг өгөөгүйн шалтгаан нь Бурханы махбод болсон бие ажлын нэг хэсгийг хийхээр ирдэг, мөн тэнгэр дэх Эцэгийг төлөөлөхөөр биш, харин ч хайртай Хүүгийн үйлчлэлийг хэрэгжүүлэхийн тулд ирдгээс л болдог. Хайртай Хүү мөрөндөө үүрсэн даалгавраа бүгдийг нь биелүүлэх үед Эцэг нь Түүнд бүрэн алдрыг Эцэгийн ялгамж чанарын хамтаар өгөх болно. Үүнийг “тэнгэрийн хууль” гэж хэлж болно. Махбодод ирсэн Нэгэн болон тэнгэр дэх Эцэг нь хоёр өөр ертөнцөд байгаа учраас энэ хоёр зөвхөн Сүнсээр бие биенээ ширтэн харж, Эцэг нь хайртай Хүүгээ ажигладаг боловч Хүү нь Эцэгээ холоос харж чаддаггүй. Мөн махбодын хийж чадах чиг үүрэг дэндүү жаахан бөгөөд Тэрээр хэдийд ч алагдах боломжтой учраас энэхүү ирэлт хамгийн их аюул агуулдаг гэж хэлж болно. Энэ нь Бурхан Өөрийн хайртай Хүүг дахин нэгэнтээ барын аманд орхин, амийг нь аюулд оруулж, Сатаны хамгийн их төвлөрдөг газарт Түүнийг тавихтай адилхан. Ийм аймшигтай орчин нөхцөлд ч гэсэн Бурхан “Түүнийг нас биед хүртэл нь өсгүүлэх” гээд бузар, садар самуун байдлаар дүүрсэн газрын хүмүүст Өөрийн хайртай Хүүг өгсөн билээ. Учир нь, Бурханы ажлыг зохистой, хэвийн байлгах цорын ганц зам энэ бөгөөд Эцэг Бурханы бүх хүслийг биелүүлж, хүн төрөлхтний дундах Түүний ажлын сүүлчийн хэсгийг хэрэгжүүлэх цорын ганц зам юм. Есүс Эцэг Бурханы ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлснээс цаашгүй. Бурханы махбод болсон биед тулгардаг саад бэрхшээл болон гүйцэлдүүлэх ажлын ялгаанаас үүдэн махбодод хоёр дахь удаагаа эргэн ирэх болно гэдгийг Есүс Өөрөө мэдээгүй. Тиймээс, Бурхан эцсийн өдрүүдэд дахин бие махбодтой болно, өөрөөр хэлбэл, Тэрээр махбод дахь ажлынхаа хоёр дахь хэсгийг хийхийн тулд махбодод дахин ирнэ гэж Библийн ямар ч тайлбарлагч, эсвэл эш үзүүлэгч тодорхой зөгнөж зүрхлээгүй юм. Тиймээс, Бурхан аль эрт Өөрийгөө махбодод нуусан гэдгийг хэн ч ухаараагүй. Есүс дахин амилж, тэнгэр өөд гарсныхаа дараа л энэ даалгаврыг хүлээн авсан учраас Бурхан хоёр дахь удаагаа бие махбодтой болох тухай ямар ч тодорхой зөгнөл байдаггүй бөгөөд үүнийг хүний оюун ухаанаар тунгаан бодох аргагүй байдагт гайхах юмгүй. Библи дэх зөгнөлийн олон номын бүгдэд нь үүнийг тодорхой дурдсан нэг ч үг байдаггүй. Харин Есүсийг ажиллахаар ирэх үед, онгон эмэгтэй хүүхэдтэй болж, хүү төрүүлнэ буюу Тэр Ариун Сүснээс олдсон гэсэн утгатай тодорхой зөгнөл аль хэдийн байлаа. Тэгсэн ч гэсэн,

[2] “Хүч чадал багатай, асар болгоомжтой байх ёстой” гэдэг нь махан биеийн бэрхшээл дэндүү их, хийсэн ажил хэтэрхий хязгаарлагдмал гэдгийг илтгэдэг.

үхэх аюултай гэдгийг нь Бурхан мөн л хэлсэн, тэгвэл өнөөдөр энэ нь бүр ч тийм байх бус уу? Энэ удаа бие махбодтой болох нь Нигүүлслийн эрин үеийнхээс хэдэн мянга дахин илүү аюултай гэж Бурхан хэлдэгт гайхах юмгүй. Бурхан Синимийн газар нутагт бүлэг ялагчдыг олж авна гэдгээ олон газарт зөгнөсөн. Дэлхийн Зүүн зүгт ялагчдыг олж авах тул хоёр дахь удаа бие махбод болсон Бурханы хөл тавьдаг газар нь ямар ч эргэлзээгүй Синимийн нутаг буюу агуу улаан лууны цагариглан хэвтэж байгаа яг тэр газар юм. Тэнд Бурхан агуу улаан лууны үр удмыг олж авснаар үүнийг бүрмөсөн ялж, шившиглэдэг. Бурхан гүн гүнзгий зовж шаналж байгаа энэ хүмүүсийг сэрээж, бүрэн сэртэл нь сэргээж, манангаас гаргаж, тэднээр агуу улаан лууг голуулах гэж байна. Тэд зүүд нойрноосоо сэрж, агуу улаан лууны мөн чанарыг таньж, бүхий л зүрх сэтгэлээ Бурханд өгч, харанхуйн хүчний дарлалаас өндийн босож, дэлхийн Зүүн зүгт зогсож, Бурханы ялалтын баталгаа болж чадна. Зөвхөн ийм маягаар л Бурхан алдрыг олж авна. Гагцхүү энэ шалтгааны улмаас, Бурхан Израильд дууссан ажлыг агуу улаан лууны цагариглан хэвтэж байгаа газарт авчирсан ба явснаасаа хойш бараг хоёр мянган жилийн дараа Нигүүлслийн эрин үеийн ажлыг үргэлжлүүлэхийн тулд дахин нэгэнтээ махбодод ирсэн юм. Хүний энгийн нүдээр бол Бурхан махбодоор шинэ ажил эхлүүлж байгаа. Харин Бурханы үзэл бодлоор бол, Тэр цөөн хэдэн мянган жилийн хугацааны зайтайгаар Нигүүлслийн эрин үеийн ажлыг үргэлжлүүлж байгаа ба зөвхөн ажлын байршил болон Түүний ажлын хөтөлбөрт өөрчлөлт гарсан. Өнөөдрийн ажилд авсан махбодын дүр Есүсээс шал өөр харагддаг хэдий ч Тэд адилхан мөн чанар, эх үндэстэй бөгөөд нэг эх сурвалжаас ирсэн. Тэд гаднаа олон ялгаатай байж болох ч Тэдний ажлын дотоод үнэн бүхэлдээ адилхан юм. Эцсийн эцэст эрин үеүд нь өдөр шөнө шиг ялгаатай. Бурханы ажил яаж өөрчлөгдөшгүй хэв маягийг дагаж болох юм бэ? Эсвэл Түүний ажлын өөр өөр үе шат бие биедээ саад болж яаж чадах юм бэ?

Есүс иудейчүүдийн төрхийг авч, иудейчүүд шиг хувцаслаж, иудейчүүдийн хоолыг идэж өссөн. Энэ нь Түүний хэвийн хүн чанарын тал юм. Гэвч, өнөөдөр Бурханы махбод болсон бие Ази иргэний төрхтэй бөгөөд агуу улаан лууны үндэстэнд өссөн. Эдгээр нь бие махбодтой болсон Бурханы зорилготой яавч зөрчилддөггүй. Харин ч тэдгээр нь нэг нэгнээ нөхөж, бие махбодтой болсон Бурханы жинхэнэ ач холбогдлыг илүү бүрэн гүйцэд болгодог. Бурханы махбод болсон биеийг “хүний Хүү” эсвэл “Христ” гэж хэлдэг учраас өнөөдрийн Христийн гадна талыг Есүс Христийнхтэй харьцуулж болохгүй. Эцсийн эцэст энэхүү махбодыг “хүний Хүү” гэж дууддаг ба энэ нь махан биеийн төрхтэй байдаг. Бурханы ажлын үе шат болгон нэлээд гүн гүнзгий утга агуулдаг. Есүс Ариун Сүнснээс олдсоны шалтгаан нь Тэр нүгэлтнүүдийг золин аврах байснаас үүдсэн юм. Тэр нүгэлгүй байх ёстой байв. Гэвч эцэстээ Тэр албан хүчээр нүгэлт махан биеийн төрхийг авч, нүгэлтнүүдийн нүглийг үүрэх үедээ л хараагдсан загалмайнаас буюу хүмүүсийг гэсгээхдээ Бурханы ашигладаг загалмайнаас тэднийг аварсан юм. (Загалмай бол хүмүүсийг хараах, гэсгээх Бурханы хэрэгсэл юм; хараах болон

гэсгээх талаар дурдах нь ялангуяа нүгэлтнүүдтэй хамаатай байдаг.) Үүний зорилго нь бүх нүгэлтнийг гэмшүүлж, цовдлолоор дамжуулан нүглийг нь улайлгах явдал байлаа. Өөрөөр хэлбэл, бүх хүн төрөлхтнийг золин аврахын төлөө Бурхан Ариун Сүнснээс олдсон бие махбодтой болж, бүх хүн төрөлхтний нүглийг Өөртөө үүрсэн юм. Үүнийг энгийн үгээр дүрсэлбэл, бүх нүгэлтний оронд Тэрээр ариун махбодыг тахил болгосон бөгөөд өөрийн гишгэлсэн гэм зэмгүй бүх хүн төрөлхтнийг Бурханд буцаан өгөхийг Сатанаас “гуйхын” тулд Есүс Сатаны өмнө нүглийн тахил болон тавигдсантай энэ нь адилхан юм. Тийм учраас, золин авралын ажлын энэ үе шатыг гүйцэлдүүлэхэд Ариун Сүнснээс олдох шаардлагатай байв. Энэ бол чухал нөхцөл, мөн Эцэг Бурхан болон Сатаны хоорондох тулааны “эвийн гэрээ” билээ. Тийм учраас, Есүсийг Сатанд өгсний дараа л ажлын энэ үе шат дууссан юм. Гэсэн хэдий ч Бурханы золин авралын ажил нь өнөөдөр урьд хожид байгаагүй сүр жавхланд хүрсэн ба шаардлага тавих ямар ч шалтаг Сатанд байхгүй тул бие махбодтой болохын тулд Бурхан Ариун Сүнснээс олдох шаардлагагүй болсон. Бурхан төрөлхийн ариун, гэм зэмгүй тул энэ удаа бие махбодтой болсон Бурхан нь Нигүүлслийн эрин үеийн Есүс байхаа больсон юм. Гэвч Тэр мөн л Эцэг Бурханы хүслийн төлөө, мөн Эцэг Бурханы хүслийг биелүүлэхийн төлөө бие махбодтой болж байгаа. Энэ нь мэдээж үндэслэлгүй тайлбар биш биз дээ? Бие махбодтой болсон Бурхан цогц дүрэм журмыг мөрдөх ёстой гэж үү?

Бурхан бие махбодтой болох тухай зөгнөлийг олно гэж найдаад олон хүн Библиэс нотолгоо хайдаг. Удаан төлөвлөсөн боловч хүнд хэзээ ч хэлээгүй ажлаа сонирхолтойгоор, тааламжтайгаар хийхийн тулд Бурхан Библи дотор “ажиллахаа” аль хэдийн больж, үүний хил хязгаарын гадна “үсрэн гарсан” гэдгийг будилсан, авцалдаагүй бодолтой хүн яаж мэдэх юм бэ? Хүмүүс эрүүл ухаанаар маш дутмаг. Бурханы зан чанарыг үл ялиг амссаныхаа дараа тэд тавцан суурилуулж, өндөр зэрэглэлийн “тэргэнцэр” дээр огт хайхрамжгүй суун Бурханы ажлыг хянан шалгаж, нарны доорх бүх зүйлийн тухай гоёмсог авцалдаагүй яриагаар Бурханыг сургаж эхлэхдээ тулдаг. Томруулдаг шил зүүж, сахлаа илсэн олон “хөгшин хүн” насан туршдаа уншсан шарласан “хуучин литээ” (Библиэ) дэлгэдэг. Үг бувтнаж, нүд нь цог жавхаатай гялалзах тэр хүн одоо Илчлэлийн Номыг, тэгээд Даниелийн номыг дараа нь хүн бүрийн сайн мэддэг Исаиагийн Номыг ээлжлэн нээдэг. Жижигхэн үгс шигүү бичигдсэн хуудас руу ээлж дараалан ширтээд тэрээр чимээгүйхэн унших ч уураг тархи нь тасралтгүй эргэцүүлнэ. Гэнэтхэн гар нь сахлаа илж байснаа болиод, угзарч эхэлдэг. Эрт орой нэгэн цагт сахлынх нь тасрах чимээ сонсогдоно. Тийм хачирхалтай авир хүний гайхлыг төрүүлдэг. “Яагаад тийм их хүч хэрэглэнэ вэ? Юунд тэгж их уурлана вэ?” Хөгшин хүнийг дахин нэгэнтээ харвал хөмсөг нь одоо арзайжээ. Тэр хөгшин хөгцөрсөн мэт харагдах хуудаснуудаас нүд салгахгүй байх зуур бууралтсан хөмсөг нь галууны өд мэт, хөгшний зовхиноос яг хоёр сантиметрийн зайд, санаандгүй атлаа маш төгс зохицсон мэт доош буужээ. Тэрээр нэг хуудсыг хэд хэдэн удаа эргэн харсны эцэст өөрийн эрхгүй хөл дээрээ үсрэн, хэн

нэгэнтэй дэмий ярьж[3] байгаа мэт чалчиж эхэлнэ, гэсэн ч түүний нүднээс цацрах гэрэл литийг орхисонгүй. Гэнэт тэр тухайн хуудсаа хааж, “өөр ертөнц” рүү эргэдэг. Түүний хөдөлгөөн маш их яарсан[4], айдас хүргэм бөгөөд хүмүүсийг бараг гайхшируулдаг. Одоо, түүнийг чимээгүй байх зуур нүхнээсээ гарч ирээд, дөнгөж тайвширч, чөлөөтэй хөдөлж эхэлж байсан хулгана түүний гэнэтийн хөдөлгөөнөөс маш их цочин сандарсандаа нүх рүүгээ буцан гүйж, дахин хэзээ ч гарч ирэхгүйгээр утаа мэт арилна. Одоо энэ хөгшний зүүн гар түр зуур зогсоосон хөдөлгөөнөө сэргээж, сахлаа дээш доош, дээш доош илнэ. Тэр суудлаасаа холдож, ширээн дээр номоо үлдээжээ. Хаалганы завсар болон онгорхой цонхоор салхи орж ирээд, өршөөлгүйгээр үлээн номыг нэг хааж, нэг нээнэ. Энэ дүр зургийн тухайд бол, үгээр илэрхийлэх аргагүй эзгүйрсэн байдалтай байдаг ба номын хуудаснууд салхинд шаржигнах чимээг үл тооцвол бүх бүтээл нам гүм болсон мэт санагдана. Тэрээр нуруугаа үүрэн, өрөөн дотор хойш урагш холхиж, нэг зогсож, нэг алхан, үе үе толгойгоо сэгсэрч, амандаа “Өө! Бурхан минь! Та үнэхээр тэгнэ гэж үү?” хэмээх үгийг давтаж байгаа мэт харагддаг. Бас үе үе толгой дохин “Өө Бурхан минь! Таны ажлыг хэн ухан ойлгож чадах билээ? Таны мөрийг хайх нь хэцүү бус уу? Шалтгаангүйгээр төвөг удах зүйл хийхгүй гэдэгт тань би итгэж байна” гэдэг. Одоо тэр хөгшин алгуурхнаар сайтар бодохыг хүсэж байгаа мэт хөмсгөө зангидаж, нүдээ тас анин, сандарсан царай гаргахын зэрэгцээ тун их зовсон нүүрний хувирал харуулна. Хөөрхий хөгшин! Бүх насаараа амьдарчхаад, нэлээд хожимдсон хойноо “харамсалтайгаар” ийм асуудалтай тулгарчээ. Үүнийг яах ч билээ дээ? Би ч гэсэн арга мухардаж, яах ч аргагүй байна. Түүний хуучин лит шарласан нь хэний буруу вэ? Сахал, хөмсөг нь цагаан цас адил нүүрнийх нь өөр өөр хэсгийг хайр найргүйгээр бүрхсэнд хэн буруутай вэ? Сахлынх нь үс түүний ахмад насыг төлөөлдөг мэт. Гэсэн ч хүн Бурханы байгааг хуучин литээс хайх хүртлээ мунхаглана гэж хэн мэдэх билээ? Хуучин лит хэчнээн хуудастай байж чадах билээ? Энэ нь Бурханы бүх үйл хэргийг нарийн зөв тэмдэглэж үнэхээр чадах уу? Хэн үүнийг баталгаажуулж зүрхлэх вэ? Гэсэн ч хүн үгийг задлан шинжилж, дэмий юмаар хөөцөлдсөнөөр[5] Бурханы илрэлтийг эрж хайж, Бурханы хүслийг хангана гэж үнэхээр бодож, улмаар амь руу орно гэж найддаг. Амь руу орохоор оролдох нь сонсогдож байгаа шигээ амархан гэж үү? Энэ нь хамгийн хөгийн утгагүй, буруу ташаа үндэслэл биш гэж үү? Чамд инээдтэй санагдахгүй байна уу?

---

[3] “Дэмий ярих” гэдэг нь Бурханы ажлыг судлах үеийн хүмүүсийн муухай нүүр царайг хэлсэн зүйрлэл юм.

[4] “Яарсан” гэдэг нь “хөгшин хүн” Библиэс лавлахдаа тэсэн ядсан, яаруу тэвдүү үйл хөдлөл хийхийг хэлдэг.

[5] “Үгийг задлан шинжилж, дэмий юмаар хөөцөлдөх” гэдэг нь үгээс болж дэмий юмаар хөөцөлддөг мөртөө үнэнийг эрж хайдаггүй, эсвэл Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, гажууд онолын мэргэжилтнүүдийг дооглохын тулд хэрэглэгдсэн.

АЖИЛ БА ОРОЛТ 7

Хүнд дутагддаг зүйл нь сүнслэг амийн хангалт, Бурханыг мэдэх туршлага төдийгүй, түүнээс ч амин чухал зүйл нь тэдний зан чанар дахь өөрчлөлт юм гэдгийг хүн өнөөдөр л ухаарчээ. Түүх болон өөрийнхөө угсаатны эртний соёлын талаар бүрэн мэддэггүйнхээ үрээр хүн Бурханы ажлын талаар огт юу ч мэддэггүй. Зүрх сэтгэлийнхээ гүнд Бурхантай нэгдэж чадна гэж бүх хүн найддаг боловч махан бие нь дэндүү завхарсан, хөшүүн агаад мулгуу байдаг учраас хүнийг Бурханы талаар огт юу ч мэддэггүй болгосон. Өнөөдөр хүмүүсийн дунд ирсэн Бурханы зорилго нь гагцхүү хүмүүсийн бодол, сүнсийг, мөн түүнчлэн олон сая жилийн турш хүний зүрх сэтгэлд байсан Бурханы дүрийг өөрчлөх явдал юм. Тэрээр энэ боломжийг ашиглан хүнийг төгс болгоно. Өөрөөр хэлбэл, Түүнийг мэдэж авах хүмүүсийн арга зам болон Түүнд хандах хандлагыг мэдлэгээр нь дамжуулан өөрчилж, Бурханыг мэдэж авахдаа цоо шинээр эхлэх боломжийг хүнд олгон, улмаар хүний сүнсийг шинэчилж, өөрчилнө. Харьцалт, сахилгажуулалт нь арга барил, харин байлдан дагуулалт, шинэчлэлт нь зорилго юм. Тодорхойгүй Бурханы талаар хүний өвөрлөж байсан мухар сүсэгт бодол санааг арилгах нь үргэлжид Бурханы санаа зорилго байсаар ирсэн ба сүүлийн үед энэ нь бас Түүний хувьд яаралтай хэрэг болсон. Энэхүү нөхцөл байдлыг авч үзэхдээ бүх хүн холыг харна гэж найдъя. Хүн бүрийн туршлагажих арга замыг өөрчил, ингэснээр Бурханы энэхүү яаралтай санаа зорилго удалгүй үр дүнд хүрч, газар дээрх Бурханы ажлын сүүлчийн үе шат бүрмөсөн гүйцэлдэж болох юм. Бурханд өгвөл зохих үнэнч байдлыг та нар Түүнд өгч, эцсийн удаа Бурханы зүрх сэтгэлийг тайтгаруул. Ах эгч нарын дундаас хэн нь ч энэ хариуцлагаас зайлсхийх юм уу зүгээр л хийсэн дүр үзүүлэх ёсгүй. Бурхан энэ удаа урилгын хариуд болон хүний нөхцөл байдалд чиглэсэн хариу болгон махбодод ирдэг. Өөрөөр хэлбэл, Тэр хүнийг хэрэгтэй зүйлээр нь хангахын тулд ирдэг. Хүний хэв чанар, эсвэл хүмүүжил ямар байх нь хамаагүй, товчхондоо, Тэрээр Бурханы үгийг хүнд харуулан, Түүний үгээс Бурханы оршин тогтнол, илрэлийг харж, Бурхан өөрийг нь төгс болгохыг хүлээн зөвшөөрөх боломжийг хүнд олгож, хүний бодол санаа, үзлийг өөрчилдөг болохоор Бурханы анхдагч төрх хүний зүрх сэтгэлийн гүнд бат үндэслэдэг. Энэ бол Бурханы газар дээрх цорын ганц хүсэл билээ. Хүний төрөлх уг чанар хэчнээн агуу, хүний мөн чанар хэчнээн дорд байх нь хамаагүй, эсвэл хүний зан авир урьд нь үнэндээ ямархуу байсан нь хамаагүй, Бурхан эдгээрт ямар ч анхаарал хандуулдаггүй. Хүн өөрийнхөө дотоод сэтгэл дэх Бурханы дүр төрхийг бүрэн шинэчилж, хүн төрөлхтний мөн чанарыг мэдэж авч, улмаар хүний үзэл суртлын төлөв өөрчлөгдөж, Бурханыг зүрх сэтгэлийнхээ гүнээс хүсэн эрмэлзэж, Түүнтэй мөнхийн холбоотой байж чадна гэж Бурхан найддаг: Энэ бол хүнд Бурханы тавьдаг цорын ганц шаардлага билээ.

Хэдэн мянган жилийн турш үргэлжилсэн эртний соёл болон түүхийн тухай мэдлэг нь хүний сэтгэлгээ, үзэл болон оюун санааны төлвийг нэвтэршгүй,

задаршгүй[1] болтол маш ягштал чанга битүүмжилсэн юм. Хүмүүс тамын арван найм дахь хүрээнд амьдарч, тэндээ яг л газар доорх гяндан руу Бурханаар цөлөгдөөд хэзээ ч гэрэл хардаггүй мэт байдаг. Мөн феодалын сэтгэлгээ нь хүмүүсийг маш их дарангуйлсан болохоор арайхийн амьсгалж, амьсгал нь боогдож байгаа мэт байдаг. Үүнийг эсэргүүцэх өчүүхэн ч хүч тэдэнд байдаггүй; тэд дуугүйхэн тэвчихээс өөрийг хийдэггүй… Хэн ч, хэзээ ч зөв шударга байдал, шударга ёсны төлөө тэмцэж, эсвэл өндийн босож зүрхлээгүй; хүмүүс өдрөөс өдөрт, жилээс жилд феодал эздийн цохилт, хүчирхийлэл доор амьтныхаас дор амьдралаар амьдардаг. Хүний ертөнцөд аз жаргал эдлэхийн тулд Бурханыг эрж хайя гэж тэд хэзээ ч бодоогүй. Хүмүүс гандаж, хатаад, шаргалтан унаж буй намрын навчис шиг болтлоо зодуулсан мэт байдаг. Хүмүүс ой санамжаа хэдийнээ алдсан; тэд хүний ертөнц гээч тамд арга мөхөстөн амьдарч, энэхүү тамтайгаа хамт мөхөхийн тулд эцсийн өдөр ирэхийг хүлээн, хүсэн эрмэлздэг эцсийн өдөр нь амар амгаланг эдлэх өдөр нь мэт байдаг. Феодалын ёс зүй хүний амьдралыг “Үхэгсдийн орон” руу аваачиж, улмаар хүний эсэргүүцэх чадварыг сулруулжээ. Төрөл бүрийн дарангуйлал нь хүнийг алхам алхмаар Үхэгсдийн орон руу илүү гүн унагаж, Бурханаас улам холдуулснаар өнөөдөр хүн Бурханыг огт танихгүй болсон бөгөөд тааралдах үедээ Бурханаас зайлсхийхээр яаравчилдаг. Хүн урьд нь Түүнийг хэзээ ч мэддэг байгаагүй мэт, мөн хэзээ ч харж байгаагүй мэт Түүнийг анхаардаггүй ба нэг талд ганцааранг нь орхидог. Гэсэн ч Бурхан амьдралынх нь урт удаан аяны туршид хүнийг хүлээн, Өөрийн номхоршгүй уур омгийг хүн рүү хэзээ ч чулуудалгүй, хүний гэмшиж, шинээр эхлэхийг л чимээгүйхэн, ганц ч үг хэлэлгүй хүлээсээр ирсэн юм. Бурхан хүний ертөнцийн зовлонг хүнтэй хуваалцахаар аль хэдийн хүний ертөнцөд ирсэн. Хүнтэй хамт амьдарсан энэ бүх хугацаанд хэн ч Түүний оршин тогтнолыг олж илрүүлээгүй. Бурхан биечлэн авчирсан ажлаа хэрэгжүүлэх зуураа хүний ертөнц дэх ядуу байдлын зовлон зүдгүүрийг чимээгүйхэн л тэвчдэг. Тэрээр Эцэг Бурханы хүсэл болон хүн төрөлхтний хэрэгцээний төлөө тэвчсээр байж, урьд өмнө нь хүний хэзээ ч туулж байгаагүй зовлонг туулдаг. Эцэг Бурханы хүслийн төлөө, бас хүн төрөлхтний хэрэгцээний төлөө Тэрээр хүний өмнө чимээгүйхэн үйлчилж, Өөрийгөө даруу байлгасан юм. Эртний соёлын талаарх мэдлэг нь хүнийг Бурханы өмнөөс сэмхэн хулгайлж, диаволуудын хаан болон түүний үр удамд өгсөн. Дөрвөн Ном ба Таван Сонгодог[a] нь хүний сэтгэлгээ болон үзлийг өөр нэг тэрслүү эрин үе рүү аваачиж, Ном/Сонгодог зохиолыг эмхэтгэсэн хүмүүсийг урьдынхаасаа бүр их бишрэхэд хүнийг хүргэж, улмаар Бурханы талаарх эндүү ташаа үзлийг нь улам нэмэгдүүлсэн юм. Хүнд мэдэгдэлгүйгээр диаволуудын хаан Бурханыг хүний зүрх сэтгэлээс хайр найргүйгээр хөөгөөд, дараа нь өөрөө хүний сэтгэлийг баяр

[1] “Задаршгүй” гэдэг нь энд егөөдөх зорилготой бөгөөд хүмүүсийн мэдлэг, соёл, сэтгэл санааны байдал хөшүүн байдаг гэсэн утгатай.

[a] Дөрвөн Ном ба Таван Сонгодог нь Хятад дахь Күнзийн сургаалын нэр нөлөөтэй ном юм.

хөөртэйгээр эзэмджээ. Тэр үеэс хойш хүн муухай, хорон муу сэтгэлтэй, диаволын хааны царай төрхтэй болсон юм. Бурханд хандах үзэн ядалт түүний цээжийг дүүргэсэн ба диаволуудын хааны хорон санаа нь хүнийг бүрэн автах хүртэл өдрөөс өдөрт дотор нь тархдаг. Хүн өчүүхэн төдий ч эрх чөлөөтэй байхаа больж, диаволуудын хааны урхинаас ангижрах аргагүй байлаа. Хүн тэр дороо баривчлагдан, түүний өмнө бууж өгч, хүлцэнгүйгээр унахаас өөр сонголтгүй болжээ. Аль эрт хүний сэтгэл, зүрх нялх балчир хэвээр байх үед диаволуудын хаан бурхангүй үзлийн хавдрын үрийг суулгаж, “шинжлэх ухаан, технологийг судалж, Дөрвөн Шинэчлэлтийг биелүүл, дэлхий дээр Бурхан гэгч зүйл үгүй” гэх мэт төөрөгдлийг хүнд заасан. Түүгээр ч зогсохгүй, “Үйлдвэрлэлийн ажил хөдөлмөртөө түшиглэн сайхан эх орныг бүтээцгээе” хэмээн боломж олдох бүрд хашхирч, улс орныхоо төлөө үнэнчээр зүтгэхийн тулд бага наснаасаа эхлээд бэлдэхийг хүн нэг бүрээс шаарддаг. Хүн өөрийн эрхгүй түүний өмнө хүргэгдсэн бөгөөд тэр эргэлзэлгүйгээр бүх гавьяаг нь (бүх хүн төрөлхтнийг гартаа барьж байдаг Бурханд харьяалагдах гавьяаг гэсэн үг) өөртөө авсан. Түүнд ичих мэдрэмж хэзээ ч байгаагүй. Түүнчлэн, энэ нь Бурханы ардыг ичгүүр сонжуургүйгээр булаан авч, гэр лүүгээ буцаан чирээд, ширээн дээр хулгана шиг үсрэн гарч, хүнээр өөрийгөө Бурхан мэт шүтүүлсэн. Тийм цөхөрсөн амьтан! Энэ нь: “Дэлхий дээр Бурхан гэгч зүйл байхгүй. Салхи байгалийн хуулийн дагуу хувирлаас үүсэн гардаг; ус ууршиж, хүйтэн агаарт гарах үедээ конденсацлагдан, газар дээр бороо болон дусалдаг; газар хөдлөлт бол геологийн өөрчлөлтөөс үүдэн газрын гадарга чичрэх явдал юм; нарны гадаргуу дээрх цөмийн дэлбэрэлтээс болж үүссэн агаарын хуурайшлын улмаас ган гачиг болдог. Эдгээр нь бүгд байгалийн үзэгдэл. Хаана нь Бурханы үйл хэрэг байгаа юм бэ?” гэх мэт гүжирдсэн, цочирдмоор зүйл хашхирдаг. Тэр ч бүү хэл, дараахтай адил ичгүүргүй үг хэллэг хашхирдаг хүмүүс ч бий: “Хүн эрт цагт бичээс хувьсаж бий болсон ба өнөөдрийн дэлхий ертөнц ойролцоогоор олон зуун жилийн тэртээх хүй нэгдлийн нийгмээс залгамжлан бий болсон. Улс орон хөгжин цэцэглэж, уруудан доройтох эсэх нь бүхэлдээ ард түмнийх нь гарт байдаг.” Ардуур нь, диаволын хаан өөрийгөө тахиулж, шүтүүлэхийн тулд хүнээр өөрийгөө ханан дээр өлгүүлэх юм уу ширээн дээр тавиулдаг. “Ямар ч Бурхан байдаггүй” хэмээн хашгирахын зэрэгцээ энэ нь өөрийгөө Бурхан болгон тавьж, Бурханыг газар дэлхийн зах хязгаарааас цааш бүдүүлгээр түлхэх зуураа Бурханы оронд зогсож, диаволуудын хааны үүрэг гүйцэтгэдэг. Үнэхээр эрүүл ухаангүй! Энэ нь хүнийг, өөрийг нь голдоо ортол үзэн ядахад хүргэдэг. Бурхан, тэр хоёр заналт дайснууд бөгөөд зэрэгцэн оршиж чадахгүй мэт санагддаг. Энэ нь хуулиас гадуур, эрх чөлөөтэй хэрэн хэсэх[2] зуураа Бурханыг хөөн зайлуулах арга сийлж байдаг. Үнэхээр диаволуудын хаан! Бид үүний оршин тогтнолыг яаж тэвчиж болох юм бэ? Энэ нь

[2] “Хуулиас гадуур, эрх чөлөөтэй хэрэн хэсэх” гэдэг нь диавол зэрлэг догшноор, галзуурсан мэт явдаг гэдгийг илтгэдэг.

Бурханы ажлыг үймүүлж, бүхэлд нь бүрмөсөн эмх замбараагүй[3] болгож орхих хүртлээ амрахгүй бөгөөд эцсээ хүртэл, үхэх сэхэхээ үзэн Бурханыг эсэргүүцэхийг хүсэж байгаа мэт, Бурханыг зориуд сөргөж, улам ойртон давшилдаг. Жигшүүрт царай хэдийнээ бүрэн ил болсноор энэ нь одоо гэмтэж, навсайсан[4] хүнд бэрх байдалд орсон ч Бурханыг үзэн ядах нь багасалгүй, ганцхан үмхэлтээр Бурханыг залгиснаар л зүрх сэтгэлдээ хураасан үзэн ядалтаа арилгаж чадах юм шиг байдаг. Бурханы энэхүү дайсныг бид яахан тэвчиж чадах билээ! Үүнийг үндсээр нь устгаж, бүрэн сөнөөж байж л амьдралын маань хүсэл биелнэ. Галзуурсан мэт үргэлжлүүлэхийг нь яаж зөвшөөрч болох юм бэ? Хүн тэнгэрнарыг мэддэггүй, үхээнц, мэдрэмжгүй болох хүртэл энэ нь хүнийг завхруулсан юм. Хүн хэвийн хүний эрүүл ухааныг алдсан. Ирээдүйн төлөөх бүх санаа зовнилыг арилгаж, Бурханы ажлыг урьд өмнө үзэгдээгүй сүр жавхланд хурдхан хүргэхийн тулд үүнийг устгаж, шатаахад бүхий л оршихуйгаа зориулж яагаад болохгүй гэж? Энэ өөдгүй бүлэг этгээд хүний ертөнцөд ирж, үймээн самуунтай болгосон. Тэд бүх хүнийг ангалын ирмэгт аваачиж, тэднийг доош түлхэн хэдэн хэсэг болгоод, дараа нь цогцсыг нь залгихаар нууцхан төлөвлөсөн. Тэд Бурханы төлөвлөгөөг нураахаар дэмий найдаж, Бурхантай тэмцэлдэн, эрсдэлтэй бооцоонд бүхнээ тавьдаг.[5] Энэ нь яавч амархан биш! Эцсийн эцэст, хамгийн жигшүүрт гэмт хэрэг үйлдсэн диаволын хаанд зориулсан загалмай бэлтгэгдчихсэн. Бурхан загалмайд харьяалагддаггүй. Тэрээр үүнийг диавол руу аль хэдийн шидчихсэн. Бурхан аль эрт ялгууснаар гарч ирээд, хүн төрөлхтний нүгэлд харамсан гашуудахаа больсон боловч бүх хүн төрөлхтөнд аврал авчирна.

Дээрээс доошоо, эхлэлээс төгсгөл хүртэл Сатан Бурханы ажлыг үймүүлж, Түүнийг эсэргүүцэн авирласаар ирсэн. “Эртний соёлын өв”, үнэ цэнтэй “эртний соёлын мэдлэг”, “Даосизм болон Күнзийн сургаал”, “Күнзийн сонгодог бүтээл болон феодалын ёс заншил” зэрэг энэ бүх яриа нь хүнийг тамд аваачсан. Орчин үеийн дэвшилтэт шинжлэх ухаан, технологи, түүнчлэн өндөр хөгжсөн аж үйлдвэр, хөдөө аж ахуй, бизнес хаа ч харагддаггүй. Харин ч, Бурханы ажлыг зориуд үймүүлж, эсэргүүцэж, нураахын тулд эртний “бичнүүдийн” дэлгэрүүлсэн феодалын ёс заншлыг л цохон тэмдэглэдэг. Энэ нь өнөөг хүртэл хүнийг зовоон шаналгаад зогсохгүй, бүр хүнийг бүхлээр нь залгихыг[6] хүсдэг. Феодализмын ёс суртахуун, ёс зүйн сургаал дамжиж, эртний соёлын мэдлэг өвлөгдөн ирсэн нь хүнд аль хэдийн

---

[3] “Бүрмөсөн эмх замбараагүй” гэдэг нь диаволын хэрцгий зан авир харж тэвчихийн аргагүй байдгийг хэлдэг.

[4] “Гэмтэж, навсайсан” гэдэг нь диаволын хааны үзэшгүй муухай царайг хэлдэг.

[5] “Эрсдэлтэй бооцоонд бүхнээ тавих” гэдэг нь эцэст нь хожно гэж найдан бүх мөнгөө ганцхан бооцоонд тавих гэсэн үг юм. Энэ нь диаволын өөдгүй муу, олиггүй арга зальд зориулсан зүйрлэл юм. Энэ илэрхийллийг тохуурхан хэрэглэсэн.

[6] “Залгих” гэдэг нь диаволуудын хааны догшин хэрцгий зан авирыг хэлдэг ба энэ нь хүмүүсийг тэр чигт нь цөлмөдөг.

нөлөөлж, тэднийг том, жижиг диаволууд болгон хувиргажээ. Бурханыг баяртайяа хүлээж авч, Бурханыг ирэхэд баярлан угтах хүн цөөхөн байдаг. Бүх хүний царай хөнөөлт санаархлаар дүүрч, үхлийн амьсгал газар сайгүй агаарт түгдэг. Тэд Бурханыг энэ газар нутгаас хөөхийг зорьдог; гартаа хутга, сэлэм бариад Бурханыг “газрын хөрснөөс арчих” тулааны байраа эзэлдэг. Бурхан байдаггүй гэж хүнд үргэлж зааж сургадаг диаволын энэ газар нутаг даяар хуурамч шүтээнүүд тархан, шатаж буй цаас, хүжний дотор муухайрам үнэр шингэсэн агаар амьсгал боогдуулам маш нягт байдаг. Энэ нь хорт могой мушгиран мурилзахад ханхалдаг хаягдал лагийн өмхий үнэр шиг байдаг болохоор хүн бөөлжихгүй байж чаддаггүй. Үүнээс гадна, ёрын муу чөтгөрүүд бичвэрийг аялгуулан уншиж байгаа чимээг тэндээс дөнгөн данган сонсож болох ба энэ чимээ тамын гүнээс гарч байгаа мэт санагддаг болохоор өөрийн эрхгүй нуруугаар хүйт даадаг. Энэ газар нутагт солонгын долоон өнгөтэй хуурамч шүтээнүүдийг хаа сайгүй тавиад, уг газрыг нүд гялбам ертөнц болгон хувиргах зуураа олиггүй явуулга нь амжилттай болсон мэт диаволуудын хаан хорлонтойгоор инээсээр байдаг. Харин тэгэхэд хүн юу ч мэдэхгүй хэвээр үлддэг бөгөөд диавол өөрийг нь эрүүл ухаангүй болж, ялагдан толгой гудайх хүртэл нь хэдийнээ завхруулсан гэдгийг ч хүн мэдэхгүй. Диавол, Бурханы бүх юмыг нэг цохилтоор л бүрмөсөн устгаж, Түүнийг дахин доромжилж, хөнөөхийг хүсдэг; тэгээд Түүний ажлыг нурааж, үймүүлэхээр санаархдаг. Эн тэнцүү байр суурьтай байхыг энэ нь яаж Бурханд зөвшөөрч чадах билээ? Газар дээрх хүмүүсийн дундах ажилд нь Бурхан “хөндлөнгөөс оролцохыг” яаж тэвчиж чадах билээ? Жигшүүртэй нүүр царайг нь илчлэхийг Бурханд зөвшөөрч яахан чадах билээ? Өөрийнх нь ажлыг замбараагүй болгохыг Бурханд зөвшөөрч яахан чадах билээ? Уур хилэн нь буцалж буй энэ диавол, газар дээрх хаант улсынх нь шүүхийг захирахыг Бурханд зөвшөөрч яахан чадах билээ? Бурханы дээд хүчинд дуртайяа бөхийж яахан чадах билээ? Түүний жигшүүрт үнэн төрх юу вэ гэдэг нь илчлэгдсэн, ингэснээр хүн инээх үү, уйлах уу гэдгээ мэдэхээ больдог ба энэ талаар ярихад үнэхээр хэцүү. Үүний мөн чанар энэ биш гэж үү? Муухай сэтгэлтэй тэрээр өөрийгөө итгэхийн аргагүй үзэсгэлэнтэй сайхан гэж итгэсээр байдаг. Гэмт хэргийн хамсаатнуудын[7] бүлэг! Тэд зугаа цэнгэлд умбаж, үймээн самуун өдөөхийн тулд мөнх бус ертөнцөд буун ирээд, маш их үймээн дэгдээдэг болохоор дэлхий ертөнц хувирамтгай, тогтворгүй газар болж, хүний зүрх сэтгэл айдас хүйдэс, түгшүүрээр дүүрдэг бөгөөд тэд хүнээр маш их тоглосон болохоор хүний царай талын догшин араатных шиг, туйлын муухай болж, анхдагч ариун хүний эцсийн ул мөр арилсан юм. Үүнээс гадна, тэд газар дээрх дээд эрх мэдлийг авахыг хүсдэг. Тэд, арай ядан урагшилтал нь Бурханы ажилд маш их саад хийдэг бөгөөд хүнийг зэс, ган хана мэт чанд битүүмжилсэн. Маш олон ноцтой нүгэл үйлдэж, маш их гамшиг учруулчхаад тэд гэсгээлтээс өөр зүйл хүлээж яаж чадна вэ? Чөтгөрүүд болон муу ёрын сүнснүүд

[7] “Гэмт хэргийн хамсаатнууд” гэдэг нь “бүлэг балмад этгээд” гэдэгтэй адилхан.

хэсэг зуур газар дээр галзуурсан мэт гүйж, Бурханы хүсэл болон уйгагүй хичээл чармайлтын аль алийг нэвтэршгүй болтол нь чанд битүүмжилсэн. Энэ бол үнэхээр аймшигт нүгэл! Бурхан яаж санаа зовохгүй байж чадах юм бэ? Бурхан яаж хилэгнэхгүй байж чадах юм бэ? Тэд Бурханы ажилд ноцтой саад учруулж, үүнийг эсэргүүцсэн: Дэндүү тэрслүү! Том, жижиг тэр чөтгөрүүд арслангийн хөл доорх цөөвөр чоно адил авирлаж, ёрын муу урсгалыг даган, замдаа үймээн самуун дэгдээдэг. Үнэнийг мэдээд ч тэд зориуд эсэргүүцдэг, энэ тэрслүү хөвгүүд! Одоо тамын хаан нь хааны сэнтийдээ заларсан мэт тэд маадгар, сэхүүн болчихоод бусдыг басамжилдаг. Тэдний хэд нь үнэнийг эрж хайж, шударга байдлыг дагадаг вэ? Тэд бүгдээрээ гахай, нохойноос өөрцгүй араатнууд бөгөөд овоолсон өтөг баасан дунд өмхий ялаануудын бүлгийг тэргүүлэн, сэхүүн байдлаар өөртөө баяр хүргэн толгойгоо сэгсэрч, элдэв янзын төвөг удаж[8] байдаг. Тэд өөрсдөө өмхий ялаанаас цаашгүй гэдгээ мэдэлгүйгээр, тамын хаан нь бүгдээс агуу хаан мөн гэж боддог. Түүгээр ч зогсохгүй, тэд гахай, нохой эцэг эхийнхээ хүчийг далимдуулан, Бурханы оршин тогтнолыг гүжирддэг. Өчүүхэн жаахан ялаанууд тэд эцэг эхийгээ цэнхэр халим[9] шиг том гэж итгэдэг. Тэд өөрсдөө жижигхэн, харин эцэг эх нь тэднээс олон зуун сая дахин том, бохир заваан гахай, нохой юм гэдгийг тэд ер мэддэггүй. Тэгээд өөрсдийнхөө дорд байдлыг мэдэлгүйгээр тэдгээр гахай, нохойн ялгаруулсан илжирсэн үнэрт түшиглэн галзуурсан мэт гүйлдэж, ирээдүйн үе удмаа үлдээхээр хий дэмий хүсдэг ба ичихээ мэддэггүй! Нуруундаа ногоон далавчтай (тэд Бурханд итгэдэг гэж зүтгэдгийг энэ нь хэлж байна) тэд ихэмсэглэн, өөрсдийн гоо үзэсгэлэн, сэтгэл татам байдлыг хаа сайгүй сайрхангаа өөрсдийн бие дэх бузар булайг хүн рүү нууцаар шидэж байдаг. Үүнээс гадна, тэд өөрсдөдөө дэндүү сэтгэл хангалуун байж, солонгын өнгөтэй далавчаа ашиглан бузар булайгаа далдалж чадах юм шиг байдаг бөгөөд эдгээр аргаар тэд жинхэнэ Бурханы оршин тогтнолыг хяхан хавчдаг (энэ нь шашны ертөнцөд нүднээс далдуур явагддаг зүйлийг хэлж байна). Ялааны далавч дур булаам үзэсгэлэнтэй байж болох ч эцсийн эцэст энэ нь бохироор дүүрч, нянгаар бүрхэгдсэн өчүүхэн бүтээлээс цаашгүй гэдгийг хүн яаж мэдэх билээ? Гахай, нохой эцэг эхийнхээ хүчээр тэд цадиггүй харгис догшноор газар нутаг даяар галзуурсан мэт гүйдэг (Бурханыг хяхан хавчдаг шашны албан тушаалтнууд улс орны засгийн газрын хүчтэй дэмжлэгт түшиглэн жинхэнэ Бурхан болон үнэний эсрэг тэрсэлдгийг энэ нь хэлж байна). Энэ нь, Иудейн фарисайчуудын сүнс Бурханы хамтаар агуу улаан лууны үндэстэнд буюу хуучин үүрэндээ буцан ирсэн мэт байдаг. Тэд хавчлагын өөр нэг хэсгийг эхлүүлэн, хэдэн мянган жилийн өмнөх ажлаа үргэлжлүүлсэн. Доройтмол энэ бүлэг хүмүүс эцэстээ газар дээр мөхөх нь

[8] “Элдэв янзын төвөг удах” гэдэг нь чөтгөр шиг хүмүүс хяналтаас гарч, Бурханы ажилд саад хийн, эсэргүүцэж байгааг хэлдэг.

[9] “Цэнхэр халим” гэдгийг тохуурхан хэрэглэсэн. Ялаанууд маш жижиг болохоор тэдний хувьд гахай, нохойнууд шүдтэй халим мэт том харагддаг гэдгийг хэлсэн зүйрлэл юм.

лавтай! Хэдэн мянганы дараа, бузар сүнснүүд нь бүр ч их зальжин, овжин болсон харагдаж байна. Тэд Бурханы ажлыг нууцаар нураах арга замыг байнга бодож байгаа. Элбэг дэлбэг арга заль, ов мэхээрээ тэд хэдэн мянган жилийн өмнөх эмгэнэлт явдлыг эх орондоо дахин сэргээхийг хүсэж, Бурханыг бараг хашхиртал нь өдөөн хатгадаг бөгөөд Бурхан тэднийг ор мөргүй устгахаар гурав дахь тэнгэр лүү буцахаар байж яддаг. Хүн Бурханыг хайрлахын тулд Бурханы хүслийг ухаарч, баяр хөөр, уйтгар гунигийг нь мэдэж, Тэр юуг үзэн яддагийг ойлгох ёстой. Үүнийг хийх нь хүний оролтыг бүр ч их зоригжуулна. Хүний оролт хурдан байх тусам, Бурханы хүсэл төдий чинээ хурдан хангалуун болдог ба хүн диаволуудын хааныг тодорхой харах тусмаа Бурхан руу улам ойртож, Бурханы хүслийг биелүүлнэ.

АЖИЛ БА ОРОЛТ 8

Бурханы эцсийн өдрүүдийн ажил нь хүн бүрийн сүнсийг өөрчилж, хүн болгоны оюун санааг өөрчлөхийн төлөө байдаг болохоор асар их гэмтэл авсан зүрх сэтгэл нь сэргэж, улмаар ёрын мууд маш гүн гүнзгий хорлогдсон сэтгэлийг нь авардаг гэж Би маш олон удаа хэлсэн; энэ нь хүмүүсийн сүнсийг сэргээж, хүйтэн сэтгэлийг нь гэсгээж, тэдэнд сэргэх боломж олгохын төлөө байдаг. Энэ бол Бурханы хамгийн агуу хүсэл юм. Хүний амь болон туршлага хэчнээн сүрлэг, эсвэл гүн гүнзгий болох тухай ярихаа түр хойш тавья; хүмүүсийн зүрх сэтгэл сэргэж, тэд зүүднээсээ сэрээд, агуу улаан лууны учруулсан хор хөнөөлийг сайн мэдэх үед Бурханы үйлчлэлийн ажил дууссан байх болно. Бурханы ажил дуусдаг өдөр нь бас хүн Бурханд итгэх зөв замыг албан ёсоор эхлүүлдэг өдөр юм. Энэ үед Бурханы үйлчлэл төгсөлдөө очсон байх болно: Махбод болсон Бурханы ажил бүрмөсөн дууссан байх ба хүн биелүүлэх учиртай үүргээ албан ёсоор биелүүлж эхэлнэ—тэрээр үйлчлэлээ хэрэгжүүлнэ. Энэ нь Бурханы ажлын алхмууд юм. Тиймээс та нар эдгээр зүйлийг мэдсэн суурин дээрээс өөрсдийн орох замыг олох ёстой. Энэ бүхэн нь та нарын ойлгох ёстой зүйл юм. Хүний зүрх сэтгэлийн гүнд өөрчлөлт гарсан үед л оролт нь сайжирна, учир нь Бурханы ажил бол золин аврагдсан боловч харанхуйн хүчний дор амьдарсаар байгаа, хэзээ ч сэрээгүй хүнийг чөтгөрүүдийн цугладаг энэ газраас бүрэн аврахын төлөө байдаг; хүн нүглийн мянганаас чөлөөлөгдөж, Бурханы хайртай хүн болж, агуу улаан лууг бүрмөсөн цохин унагааж, Бурханы хаанчлалыг байгуулж, Бурханы зүрх сэтгэлийг даруй амраахын төлөө; мөн цээжин дотор чинь бугшсан үзэн ядалтаа юуг ч үлдээлгүйгээр гаргаж, тэдгээр өөдгүй нянг устгаж, үхэр адууныхаас өөрцгүй энэ амьдралыг орхих боломжтой болж, боол байхаа больж, агуу улаан лууд чөлөөтэй дэвслүүлж, түүнд захирагдахаа болихын төлөө байдаг; та нар энэ бүтэлгүйтсэн улс үндэстнийх байхаа больж, жигшүүрт агуу улаан лууд харьяалагдахаа больж, түүнд боолчлогдохоо болино. Бурхан чөтгөрүүдийн үүрийг гарцаагүй хэдэн хэсэг тасчин хаях бөгөөд та нар Бурханы хажууд зогсоно—та нар

Бурханд харьяалагддаг, харин боолуудын энэхүү хаант улсад харьяалагддаггүй. Бурхан энэ харанхуй нийгмийг аль хэдийн голдоо ортол үзэн ядсан. Тэрээр шүдээ зуун, энэхүү хорон санаатай, жигшүүрт хөгшин могой дээр хөлөө тавихаар тэсэж ядан байгаа ба ингэснээр энэ нь хэзээ ч дахин босож чадахгүй, дахин хэзээ ч хүнийг хүчирхийлэхгүй; Бурхан үүний урьдын үйлдлүүдийг өршөөхгүй, хүнийг хууран мэхэлдгийг нь тэвчихгүй бөгөөд эрин үеүдийн туршид үйлдсэн нүгэл нэг бүрийнх нь төлөө тооцоо бодно; бүх ёрын муугийн энэ толгойлогчийг[1] Бурхан өчүүхэн төдий ч хэлтрүүлэхгүй, үүнийг бүрмөсөн устгана.

Олон мянган жилийн турш энэ нь бузрын газар байсаар ирсэн. Энэ нь тэвчихийн аргагүй бохир заваан, зовлон зүдүүрээр дүүрэн бөгөөд сүг сүнснүүд хаа сайгүй тархан, залилан мэхэлж, ул үндэсгүй буруутгаж,[2] балмад догшин, хорлонтой байж, чөтгөрийн энэ хотыг гишгэчин, цогцоснуудыг тараан хаяж орхидог; илжирсэн өмхий үнэр газар нутгийг бүрхэж, агаарт шингэдэг бөгөөд хатуу чанд хамгаалагдсан[3] байдаг. Тэнгэрээс цааших дэлхий ертөнцийг хэн харж чадах билээ? Диавол хүний биеийг бүхэлд нь чанга хүлж, хоёр нүдийг нь халхалж, амыг нь бат хамхидаг. Диаволуудын хаан өнөөг хүртэл хэдэн мянган жилийн турш догшин ширүүн авирлангаа нэвтрэхийн аргагүй чөтгөрүүдийн өргөө мэт чөтгөрт хотыг нүд салгалгүй харсаар байдаг; тэр хооронд, энэхүү сүрэг манаач нохой нь догшин харцаар ширтэж, Бурхан мэдээгүй байхад нь барьж аваад, бүгдийг нь устгаж, амар тайван, аз жаргалтай газаргүй болгоно гэдгээс гүнээ айж байдаг. Чөтгөрт хотын ийм хүмүүс яаж ер нь Бурханыг харсан байж чадах юм бэ? Тэд ер нь Бурханы энхрийлэл, хайр татам байдлыг амссан гэж үү? Хүний ертөнцийн хэрэг явдлын талаар тэд юу мэдэх юм бэ? Бурханы тэсэж ядсан хүслийг тэдний хэн нь ойлгож чадах юм бэ? Тэгвэл, бие махбодтой болсон Бурхан бүрмөсөн нуугдмал хэвээр үлддэгт гайхах юмгүй: Өршөөлгүй, догшин хэрцгий чөтгөрүүдтэй ийм харанхуй нийгэмд, нүд цавчилгүй хүмүүсийг хөнөөдөг диаволын хаан яаж хайр татам, сайхан сэтгэлтэй, ариун Бурханы оршин тогтнолыг тэвчиж чадах юм бэ? Бурханы ирэхийг магтан сайшааж, уухайлж яаж чадах юм бэ? Энэ боолууд! Тэд сайхан сэтгэлийг үзэн ядалтаар хариулдаг, аль эртнээс Бурханыг дайсан мэт харьцаж эхэлсэн, Бурхантай зүй бусаар харьцдаг, туйлын харгис хэрцгий бөгөөд Бурханыг өчүүхэн төдий ч анхаардаггүй, тонуул дээрэм хийдэг, мөс чанараа бүгдийг нь алдсан, мөс чанараа үл тоож, гэм зэмгүй хүмүүсийг мэдрэлгүй байдал руу уруу татдаг. Эртний өвөг дээдэс үү? Хайртай удирдагчид уу? Тэд бүгд Бурханыг эсэргүүцдэг! Тэд тэнгэрийн доорх бүхнийг түнэр харанхуй, эмх замбараагүй болгосон! Шашны эрх чөлөө юу? Иргэдийн хууль ёсны эрх, ашиг уу? Тэдгээр нь

---

[1] “Бүх ёрын муугийн толгойлогч” гэдэг нь хөгшин диаволыг хэлж байна. Энэхүү хэллэг дээд зэргийн дургүйцлийг илэрхийлдэг.

[2] “Ул үндэсгүй буруутгах” гэдэг нь хүмүүсийг хорлодог диаволын арга барилыг хэлж байна.

[3] “Хатуу чанд хамгаалагдсан” гэдэг нь хүмүүсийг зовоон шаналгадаг диаволын арга тун хэрцгий бөгөөд хүмүүсийг хөдөлж чадахаа больтол нь асар их хянадаг гэдгийг илтгэдэг.

бүгд нүглээ нуух заль мэх юм! Хэн Бурханы ажлыг тэврэн авсан бэ? Бурханы ажлын төлөө хэн амиа золиосолж, цусаа урсгасан бэ? Үеэс үед, эцэг эхээс хүүхдүүд хүртэл боолчлогдсон хүн Бурханыг эрээ цээргүйгээр боолчилсон—энэ нь яаж уур хилэн өдөөхгүй байж чадах юм бэ? Олон мянган жилийн үзэн ядалт сэтгэлд хурж, нүгэлт байдлын мянган жил зүрх сэтгэлд сийлэгдсэн—энэ нь яаж дургүйцэл төрүүлэхгүй байж чадах юм бэ? Бурханы өшөөг авч, Түүний дайсныг бүрмөсөн устга, цаашид хяналтаас гарах боломжийг үүнд бүү олго, дарангуйлагч мэт засаглахыг бүү зөвшөөр! Одоо цаг нь болсон: Энэ чөтгөрийн жигшүүрт царайг урж хаяад, харалган болж, төрөл бүрийн зовлон, бэрхшээл туулсан хүмүүст зовлон шаналлаасаа өндийн босож, энэ ёрын муу хөгшин диаволаас нүүр буруулах боломж олгохын тулд хүн аль хэдийн бүх хүч чадлаа дайчилж, бүх хичээл чармайлтаа зориулж, бүх төлөөсийг төлсөн. Бурханы ажилд яагаад ийм туулшгүй их саад бартааг тавина вэ? Бурханы хүмүүсийг мэхлэхийн тулд яагаад янз бүрийн арга заль хэрэглэнэ вэ? Жинхэнэ эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг хаана байна вэ? Шударга ёс хаана байна? Тайтгарал хаана байна вэ? Халуун дулаан байдал хаана байна? Бурханы ардуудыг мэхлэхийн тулд яагаад ов мэхтэй арга хэрэглэнэ вэ? Бурханы ирэлтийг дарахын тулд яагаад хүч хэрэглэнэ вэ? Өөрийн бүтээсэн газар дэлхий дээр чөлөөтэй хэрэн хэсэх боломжийг Бурханд яагаад олгодоггүй юм бэ? Толгойгоо тавиад амрах газаргүй болтол нь Бурханыг яагаад мөшгөнө вэ? Хүмүүсийн дундах халуун дулаан байдал хаана байна вэ? Хүмүүсийн дундах угталт хаана байна вэ? Бурханыг яагаад тэгж цөхрөнгөө бартал нь хүлээлгэнэ вэ? Бурханыг яагаад ахин дахин хашхирахад хүргэнэ вэ? Бурханыг яагаад хайртай Хүүгийнхээ төлөө санаа зов гэж хүчилнэ вэ? Энэхүү харанхуй нийгмийн өрөвдөлтэй манаач нохойнууд нь Өөрийн бүтээсэн дэлхийдээ чөлөөтэй ирж, очихыг Бурханд яагаад зөвшөөрдөггүй юм бэ? Шаналал, зовлон дунд амьдардаг хүн яагаад ойлгодоггүй юм бэ? Та нарын төлөө Бурхан асар их тарчлааныг тэвчиж, асар их шаналан Өөрийн хайртай Хүү, Өөрийн мах цусыг та нарт хайрласан, тэгвэл та нар яагаад хараагүй дүр үзүүлсээр байдаг юм бэ? Хүн бүрийг бүхэлд нь харахад Бурханы ирэлтийг голж, Бурханы нөхөрлөлөөс татгалздаг. Та нар яагаад ийм увайгүй байдаг юм бэ? Та нар ийм харанхуй нийгэмд шударга бус байдлыг туулахад бэлэн байна уу? Үүрдийн дайсагналаар ходоодоо дүүргэхийн оронд яагаад диаволуудын хааны “ялгадсаар” өөрсдийгөө дүүргэдэг юм бэ?

Бурханы ажлын саад бартаа хэчнээн их билээ? Хүн ер нь үүнийг мэдсэн үү? Хүмүүс гүн-шингэсэн мухар сүсгийн хэтрүүлэгт хоригдсон болохоор Бурханы жинхэнэ нүүр царайг хэн мэдэж чадах юм бэ? Тун өнгөц, утгагүй энэхүү хоцрогдмол соёлын мэдлэгтэйгээр тэд Бурханы хэлсэн үгийг яаж бүрэн ойлгож чадах юм бэ? Тэдэнтэй нүүр тулан ярилцаж, амаараа хооллосон ч гэсэн тэд яаж ойлгож чадах юм бэ? Заримдаа Бурханы үгийг үл ойшоодог мэт байдаг: Хүмүүст өчүүхэн төдий ч хариу үйлдэл байдаггүй, тэд толгойгоо сэгсрээд, юу ч ойлгодоггүй. Энэ нь яаж

сэтгэл түгшээхгүй байж чадах юм бэ? Энэхүү “хол хөндий[4], эртний соёлын түүх болон соёлын мэдлэг” нь ямар ч үнэ цэнгүй ийм бүлэг хүмүүсийг хүмүүжүүлсэн. Эртний энэ соёл—эрхэм нандин өв бол—бөөн хог хаягдал юм! Энэ нь аль хэдийн үүрдийн ичгүүр болсон бөгөөд үүнийг дурдахын ч хэрэггүй! Энэ нь хүмүүст Бурханыг эсэргүүцэх заль мэх, арга барилыг зааж, улсын боловсролын “захиалгат, зөөлөн удирдамж”[5] нь хүмүүсийг Бурханд бүр ч дуулгаваргүй болгосон. Бурханы ажлын хэсэг болгон нь туйлын хэцүү бөгөөд Түүний ажлын алхам бүр Бурханы хувьд сэтгэл түгшмээр байсан. Газар дээрх Түүний ажил хэчнээн хэцүү вэ! Газар дээрх Бурханы ажлын алхмууд асар их зовлон бэрхшээлийг агуулдаг: Хүний сул тал, дутагдал, хүүхдэрхүү зан, мэдлэггүй байдал болон хүний бүх зүйлийг Бурхан нямбай төлөвлөж, анхааралтай авч үздэг. Хүн бол өгөөшөөр барьж, эсвэл өдөөн хатгаж зүрхэлмээргүй цаасан бартай адил; үл ялиг хүрэнгүүт л тэр хазаж, эсвэл унаж, замаа алддаг бөгөөд өчүүхэн төдий л анхаарал алдвал хуучин хэвэндээ орж, Бурханыг үл тоодог, эсвэл өөрийн бие дэх бохир зүйлсэд ташуурахын тулд гахай, нохой эцэг эх рүүгээ гүйдэг. Ямар их саад тотгор вэ! Бурхан ажлынхаа алхам бүрд шахам сорилтод өртөж, бараг алхам бүрдээ асар их аюулыг сөрдөг. Түүний үгс чин үнэнч, шударга бөгөөд муу санаагүй байдаг, гэсэн ч хэн тэдгээрийг хүлээн зөвшөөрөхийг хүсдэг вэ? Хэн бүрэн дүүрэн захирагдахыг хүсдэг вэ? Энэ нь Бурхны зүрх сэтгэлийг шархлуулдаг. Тэр хүний төлөө өдөр шөнөгүй шаргуу хөдөлмөрлөж, хүний амийн төлөө сэтгэл зовнилд автаж, хүний сул талыг өрөвддөг. Ажлынхаа алхам бүрд, хэлдэг үг бүрдээ Тэр олон ээдрээ бартааг туулсан; Тэрээр үргэлж хадны завсар хавчуулагдсан мэт байж, хүний сул тал, дуулгаваргүй байдал, хүүхдэрхүү зан, эмзэг байдлын … талаар цаг үргэлжид, ахин дахин боддог. Хэн ер нь үүнийг мэдсэн юм бэ? Тэр хэнд итгэн ярьж болох юм бэ? Хэн ойлгож чадах юм бэ? Тэрээр хүний нүгэл, ноён нуруу дутмаг байдал, эргэж буцсан аашийг үргэлж үзэн яддаг бөгөөд хүний эмзэг байдалд үргэлж санаа зовж, хүний өмнө орших замыг дэнслэн боддог. Хүний үг, үйл хэргийг ажиглахдаа Тэр үргэлж өршөөл энэрэл, уур уцаараар дүүрдэг бөгөөд эдгээр зүйлийг харах нь Түүний зүрх сэтгэлд шаналал авчирдаг. Гэм зэмгүй хүн эцэст нь хөшүүн болсон; Бурхан яагаад үргэлж тэдэнд хүндрэл учруулдаг юм бэ? Мөхөс дорой хүнд цөхрөлтгүй зан үнэхээр байдаггүй; яагаад Бурхан хүнд байнга тэгж уурлах ёстой гэж? Сул дорой, хүч чадалгүй хүнд өчүүхэн төдий ч амин чанар байхаа больдог; дуулгаваргүй байдлынх нь төлөө Бурхан яагаад үргэлж түүнийг зэмлэх ёстой юм бэ? Тэнгэр дэх Бурханы заналхийллийг хэн тэсвэрлэж чадах вэ? Эцсийн эцэст хүн бол эмзэг, арга мөхөстсөн байдалтай байдаг ба хүнийг аажмаар өөрийгөө эргэцүүлэг гэсэндээ Бурхан Өөрийнхөө уурыг зүрх сэтгэлийнхээ гүнд булсан. Гэсэн ч ноцтой бэрхшээлтэй байгаа хүн Бурханы хүслийг өчүүхэн төдий ч ойлгоогүй; хүн диаволуудын хөгшин

[4] “Хол хөндий” гэдгийг тохуурхан хэрэглэсэн.

[5] “Захиалгат, зөөлөн удирдамж” гэдгийг тохуурхан хэрэглэсэн.

хааны хөл дор гишгэлүүлсэн атлаа үүнийгээ огт мэддэггүй бөгөөд үргэлж Бурхантай сөргөлддөг, эсвэл Бурханд халуун ч биш, хүйтэн ч биш ханддаг. Бурхан маш олон үг хэлсэн атал хэн ер нь тэдгээрийг ноцтойгоор авч үзсэн юм бэ? Хүн Бурханы үгийг ойлгодоггүй мөртөө сандарч тэвдэхгүй хэвээр үлдэж, ямар ч хүсэл тэмүүлэлгүй байдаг бөгөөд хөгшин диаволын мөн чанарыг хэзээ ч үнэхээр мэдэж аваагүй. Хүмүүс Үхэгсдийн оронд, тамд амьдардаг боловч далайн ёроол дахь ордонд амьдардаг гэдэгтээ итгэдэг; өөрсдийг нь агуу улаан луу хяхан хавчдаг ч өөрсдийгөө лууны улсаар “ивээгдсэн”[6] гэж боддог; өөрсдөөр нь диавол тохуурхдаг ч махан биеийн жүжиглэх өндөр чадварыг эдэлж байна гэж боддог. Тэд ямар бохир заваан, дорд өөдгүй амьтад вэ! Хүн золгүй явдалтай тулгарсан ч мэддэггүй бөгөөд энэ харанхуй нийгэмд бүтэмжгүй хэргийг ар араас нь туулдаг[7] боловч хэзээ ч сэрээгүй. Тэр өөрийгөө энхрийлдэг байдал болон боолын зан чанараас хэзээ салах вэ? Хүн яагаад Бурханы зүрх сэтгэлийг тэгтлээ их үл хайхардаг вэ? Энэ дарлал, бэрхшээлийг тэр сэм зөвтгөдөг юм уу? Харанхуйг гэрэл болгон өөрчлөх өдрийг хүсдэггүй гэж үү? Шударга бус явдлыг зөв шударга байдал, үнэн болгож дахин нэгэнтээ засаж залруулахыг тэр хүсдэггүй гэж үү? Хүмүүс үнэнийг хаяж, бодит баримтыг мушгин гуйвуулж байхад тэр зүгээр л хараад, юу ч хийхгүй байхыг хүсдэг юм уу? Энэ ад үзсэн байдлыг тэвчсээр байгаадаа тэр аз жаргалтай байдаг гэж үү? Тэр боол байхыг хүсэж байна уу? Ийм бүтэлгүй байр байдалтай боолуудтай хамт Бурханы гарт мөхөхийг хүсэж байна уу? Чиний шийдэмгий зан хаана байна вэ? Хүсэл эрмэлзэл чинь хаана байна вэ? Чиний нэр хүнд хаана байна? Ёс жудаг чинь хаана байна? Эрх чөлөө чинь хаана байна? Чи бүхий л амьдралаа[8] агуу улаан луу, диаволуудын хааны төлөө золиослохыг хүсэж байна уу? Түүгээр үхтэлээ тамлуулахдаа чи аз жаргалтай байдаг уу? Оёоргүй гүний гадаргуу эмх замбараагүй, харанхуй байдаг, харин энгийн ардууд ийм зовлон зүдүүр туулж, Тэнгэр өөд уйлж, газарт гомдоллодог. Хүн хэзээ толгой өндийн цэх явж чадах вэ? Туранхай, эцэнхий хүн яаж энэ харгис түрэмгий диаволтай тэмцэлдэж чадах юм бэ? Яагаад тэр өөрийн амьдралыг Бурханд аль болох хурдан өгдөггүй юм бэ? Яагаад тэр эргэлзэн тээнэгэлзсээр байдаг юм бэ? Бурханы ажлыг хэзээ дуусгаж чадах юм бэ? Тэгээд зорилгогүйгээр дээрэлхүүлж, дарлагдсан түүний бүхий л амьдрал эцэстээ хий дэмий өнгөрсөн байх болно; хүн яагаад ирэхдээ ч тийм их яарч, явахдаа ч тийм их яаравчилдаг юм бэ? Бурханд өгөх ямар нэгэн эрхэм нандин зүйлийг тэр яагаад хадгалдаггүй вэ? Хүн үүрдийн үзэн ядалтыг мартчихсан гэж үү?

Магадгүй олон хүн Бурханы зарим үгэнд дургүйцдэг байх, эсвэл дургүйцдэг ч үгүй, огт сонирхдог ч үгүй байх. Ямартай ч, баримтууд утгагүй үндэслэл болж

---

[6] “Ивээгдсэн” гэдэг нь үхээнц харагддаг, ямар ч ухамсаргүй хүмүүсийг тохуурхан хэрэглэгдсэн.

[7] “Бүтэмжгүй хэргийг ар араас нь туулдаг” гэдэг нь хүмүүс агуу улаан лууны газар нутагт төрсөн бөгөөд толгой өндийн цэх явж чаддаггүй гэдгийг илтгэдэг.

[8] “Бүхий л амьдралаа золиослох” гэдгийг дорд үзсэн утгаар хэлсэн.

чадахгүй; хэн ч баримтаас зөрсөн үг хэлж болохгүй. Бурхан ийм ажил хийж, хараахан гүйцээгээгүй ажлаа гүйцээж, энэ эрин үеийг төгсгөж, энэ эрин үеийг шүүж, зовлонгийн далайн ертөнцөөс гүн гүнзгий нүгэлтнүүдийг аварч, тэднийг бүрмөсөн өөрчлөхийн тулд энэ удаа махбод болсон юм. Иудейчүүд Бурханыг загалмайд цовдолж, улмаар Иудей дэх Бурханы аяллыг дуусгасан. Төд удалгүй Бурхан хүмүүсийн дунд дахин нэг удаа биечлэн ирсэн бөгөөд агуу улаан лууны улсад чимээгүйхэн хүрэлцэн ирсэн. Үнэндээ, Иудей улсын шашны нийгэмлэг Есүсийн зургийг ханан дээрээ аль хэдийн өлгөсөн бөгөөд хүмүүс амаараа “Эзэн Есүс Христ” хэмээн хашхирдаг. Хараахан гүйцэлдээгүй ажлынхаа хоёр дахь үе шатыг дуусгахаар хүмүүсийн дунд буцан оч гэсэн Эцэгийнхээ тушаалыг Есүс аль хэдийн хүлээн авсан гэдгийг тэд ер мэдээгүй. Үүний үр дүнд, Түүнийг харах үедээ хүмүүс цочирддог: Тэрээр олон эрин зуун өнгөрсөн дэлхийд төрсөн ба туйлын эгэл нэгний дүр төрхтэйгээр хүмүүсийн дунд гарч ирсэн. Үнэндээ, эрин үе өнгөрөхийн хэрээр Түүний хувцас, бүхий л харагдах байдал нь дахин төрсөн мэт өөрчлөгджээ. Тэр бол загалмайнаас буун ирж, дахин амилсан яг тэр Эзэн Есүс Христ мөн гэдгийг хүмүүс яахан мэдэх билээ? Есүс Еховатай огт адилгүй байсан шиг Түүнд шархны өчүүхэн төдий ч ул мөр үгүй. Өнөөдрийн Есүс, өнгөрөн одсон цаг хугацааны төрх байдлыг алдаад их уджээ. Хүмүүс Түүнийг яаж таньж чадах юм бэ? Тэр бол дахин амилсан Есүс мөн гэдэгт сэжигч “Томас” үргэлж эргэлздэг ба Есүсийн гар дээрх хадаасны сорвийг хараад сэтгэлээ амраахыг үргэлж хүсдэг; сорвийг нь хараагүй бол тэр үргэлж хардалт сэрдэлтийн үүлэн дээр зогсдог бөгөөд хөлөө баттай газар тавьж, Есүсийг дагах чадваргүй байдаг. Хөөрхий “Томас”—Есүс Эцэг Бурханы даалгасан ажлыг хийхээр ирсэн гэдгийг тэр яахан мэдэх билээ? Яагаад Есүс цовдлолын сорвитой байх ёстой юм бэ? Цовдлолын сорви нь Есүсийн таних тэмдэг юм уу? Тэр Эцэгийнхээ хүслийн төлөө ажиллахаар ирсэн; яагаад Тэр хэдэн мянган жилийн өмнөх иудей хүн шиг хувцаслаж, гоёж ирэх юм бэ? Бурханы авдаг бие махбодын хэлбэр Бурханы ажилд саад болж чадах уу? Энэ нь хэний онол юм бэ? Бурхан ажиллах үедээ яагаад хүний төсөөллийн дагуу байх ёстой юм бэ? Өөрийн ажлыг хийхдээ Бурхан үр дүнтэй байх гэсэн ганцхан зүйлд л анхаарлаа төвлөрүүлдэг. Тэр хуулийг дагадаггүй ба Түүний ажилд ямар ч дүрэм журам байдаггүй, тэгвэл хүн яаж үүнийг ухан мэдэж чадах юм бэ? Хүн үзэл, төсөөлөлдөө найдвал Бурханы ажлыг яаж нэвт шувт харж чадах юм бэ? Иймээс зохих ёсоор тайвширсан чинь дээр: Жижиг сажиг зүйлд бүү үймээн тарь, бас та нарын хувьд шинэ зүйлийг бүү хэтрүүлэн дэвэргэ—энэ нь өөрийгөө онигоо болгоод, хүмүүсээр шоолуулахыг чинь болиулна. Чи энэ бүх хугацаанд Бурханд итгэсэн атлаа Бурханыг мөн л мэддэггүй. Эцэстээ чи гэсгээлтэд унана; “дээд зэрэглэлд”[9] багтаж байсан чи гэсгээгдэх хүмүүсийн ангилалд хамаардаг. Өчүүхэн заль мэхээ харуулахын тулд ухаалаг арга хэрэглэхгүй байсан чинь дээр. Мөнхөөс мөнхөд нэвт шувт хардаг Бурханыг

[9] “Дээд зэрэглэл” гэдэг нь Бурханыг гал цогтойгоор эрэлхийлдэг хүмүүсийг тохуурхан хэрэглэгдсэн.

харалган байдал чинь үнэхээр ухамсарлаж чадах уу? Өнгөцхөн туршлага чинь чамд Бурханы хүслийг нэгд нэггүй харуулж чадах уу? Ихэрхүү бүү бай. Эцсийн эцэст Бурхан бол энэ ертөнцийнх биш, иймээс Түүний ажил яаж чиний бодсон шиг байж болох юм бэ?

АЖИЛ БА ОРОЛТ 9

Угсаатны хатуу уламжлал, сэтгэлгээ нь хүний цэвэр ариун, цайлган сэтгэлд эртнээс таагүй нөлөө үзүүлж ирсэн бөгөөд сэтгэл хөдлөлгүй, өөрийгөө гэх ямар ч мэдрэмжгүй мэт, өчүүхэн ч хүн чанаргүйгээр хүний сүнс рүү дайрсан юм. Энэ чөтгөрүүдийн арга барил туйлын харгис, “боловсрол”, “хүмүүжил” нь хүнийг хяддаг диаволын хааны уламжлалт арга болсон мэт байдаг. Тэрээр “гүн гүнзгий сургаалаа” ашиглан үзэшгүй муухай сэтгэлээ бүрэн нууж, хонины арьс нөмрөн хүний итгэлийг олоод, дараа нь үлбийн унтаж байгааг нь далимдуулан хүнийг бүрмөсөн залгидаг. Хөөрхий хүн төрөлхтөн—өсөж өндийсөн нутаг нь диаволын нутаг, өсгөж хүмүүжүүлсэн нэгэн нь үнэндээ өөрсдийг нь шархлуулдаг дайсан гэдгийг яахан мэдэх билээ. Гэвч хүн огт сэрдэггүй; өлсгөлөн, цангаагаа тайлчхаад өсгөсөн “эцэг эхийнхээ” “ачийг” хариулахаар бэлтгэдэг. Хүн ийм л байдаг. Өнөөдөр хүн өөрийг нь өсгөсөн хаан бол дайсан нь гэдгийг мэдэхгүй хэвээр. Газар дэлхий үхэгсдийн ясаар дүүрч, диавол солиотуудыг зогсолтгүй баясгаж, “нөгөө ертөнцөд” хүний махыг үргэлжлүүлэн үмхэлж, хүний араг ястай нэг булшинд орж, хүний ноорхой биеийн эцсийн үлдэгдлийг идэхээр хий дэмий оролддог. Гэвч хүн мэдэхгүй хэвээр байдаг бөгөөд диаволд хэзээ ч дайснаа гэж хандаагүй, харин ч түүнд чин сэтгэлээсээ үйлчилдэг. Ингэтлээ гажуудсан хүмүүс Бурханыг мэдэж огт чадахгүй. Махбод болж хүмүүсийн дунд ирээд авралын бүх ажлаа гүйцэлдүүлэх нь Бурханд амар байдаг гэж үү? Аль эрт Үхэгсдийн оронд унасан хүн Бурханы шаардлагыг биелүүлж яахан чадах билээ? Хүн төрөлхтний ажлын төлөө Бурхан олон шөнийг нойргүй өнгөрөөсөн. Бурхан өдөр хоногоо хүнтэй өнгөрөөхийн тулд дээрээс хамгийн доод ёроолд, хүний амьдардаг амьдын тамд бууж ирсэн бөгөөд хүмүүсийн дундах ноорхой байдалд хэзээ ч гомдоллоогүй, дуулгаваргүй байсных нь төлөө хүнийг хэзээ ч зэмлээгүй, харин ажлаа биечлэн гүйцэтгэх явцдаа хамгийн их доромжлол амсдаг. Бурхан юу гэж тамд харьяалагдах билээ? Бурхан амьдралаа тамд өнгөрөөж яахан болох билээ? Гэвч бүх хүн төрөлхтний төлөө, мөн бүхий л хүн төрөлхтнийг эртхэн амраахын төлөө Бурхан газар дээр ирэхийн тулд доромжлолыг тэсвэрлэж, шударга бус явдлыг туулж, хүнийг аврахын тулд “там”, “Үхэгсдийн орон”, барын үүрэнд биечлэн орсон юм. Хүн яаж Бурханыг эсэргүүцэхэд тохирох юм бэ? Бурханы талаар гомдоллох ямар шалтгаан хүнд байгаа юм бэ? Хүн яахан Бурханыг харах увайгүй зантай байж болох юм бэ? Тэнгэрийн Бурхан энэхүү ёс суртахуунгүй хамгийн бузар булай нутагт ирээд хэзээ ч гоморхоогүй, мөн хүний

талаар гомдоллоогүй, харин ч хүний сүйтгэл[1], дарлалыг чимээгүйхэн хүлээн зөвшөөрдөг. Хүний үндэслэлгүй шаардлагыг Бурхан хэзээ ч шүүмжлээгүй, хүнд хэзээ ч хэрээс хэтэрсэн шаардлага тавиагүй, мөн хүнээс хэзээ ч үндэслэлгүй зүйл шаардаагүй; Бурхан зааж сургах, гэгээрүүлэх, зэмлэх, үгээр цэвэршүүлэх, сануулах, захих, тайтгаруулах, шүүх, илчлэх гэх зэрэг хүний шаардсан бүх ажлыг зүгээр л гомдолгүйгээр хийдэг. Түүний аль алхам нь хүний амийн төлөө байгаагүй юм бэ? Хэдийгээр Бурхан хүний хэтийн ирээдүй, хувь заяаг үгүй хийсэн ч Түүний гүйцэтгэсэн аль алхам хүний хувь заяаны төлөө байгаагүй вэ? Аль нь хүнийг амьд үлдээхийн төлөө байгаагүй вэ? Аль нь хүнийг энэхүү зовлон, шөнө шиг түнэр харанхуйн хүчний дарлалаас ангижруулахын төлөө байгаагүй вэ? Аль нь хүний төлөө байдаггүй вэ? Элбэрэлт эхийн сэтгэл мэт Бурханы зүрх сэтгэлийг хэн ойлгож чадах вэ? Бурханы ирмүүн зүрх сэтгэлийг хэн ухаарч чадах вэ? Бурханы оргилуун зүрх сэтгэл, бадрангуй хүлээлтийг хүн хүйтэн, цэвдэг сэтгэл, үл хайхарсан харц, удаа дараагийн зэмлэл, доромжлол; мөн зүрх зүсэм үг, ёжлол, басамжлалаар хариулсан; хүн доог тохуу хийж, дэвсэлж, голж, үл ойлгож, гомдоллож, хөндийрч, зайлсхийж, ов мэх гаргаж, дайрч давшлан, хорсохоос өөр хариу бариагүй. Халуун дулаан үгийг нь хөмсөг зангидан, мянган хуруугаар чичлэн хүйтнээр үл ойшоосон билээ. Бурхан гагцхүү толгой гудайлган тэвчиж, номхон шар үхэр мэтээр хүмүүст үйлчлэхээс өөр яаж ч чаддаггүй.[2] Нар сар тун олон удаа улирч, Бурхан ододтой асар олон удаа нүүр учирч, маш олон удаа үүрийн гэгээгээр гараад үдшийн бүрийд эргэн ирж, эргэж хөрвөөн, Эцэгээсээ хагацахаас мянга дахин хүнд гасланг туулж, хүний дайралт, эвдэлт, харьцалт, засалтыг туулсан юм. Бурханы даруу, нуугдмал байдлыг хүн алагчлах сэтгэл,[3] шударга бус үзэл санаа, ёс бус хандлагаар хариулж, далд ажилладаг Бурханы нам гүм арга, хүлцэл, тэвчээрийг шунахай харцаар хариулсан; хүн харуусахгүйгээр Бурханыг дэвслэн хөнөөхийг хүсэж, газартай нь тэгшлэх гэж оролддог. Бурханд хүн “гойд сүйхээтэй” ханддаг бөгөөд хүний дээрэлхэж, зэвүүцдэг Бурхан олон түмэн хүний хөлд бяц дэвслүүлдэг байхад хүн толгодын хаан болж, хэмжээгүй эрх эдлэн,[4] нууцхан анхаарлын төвд байхыг хүсдэг мэт, Бурханыг хичээл зүтгэлтэй, дүрэм журмыг баримталдаг, эсэргүүцэж, хэрэг төвөг удах эрхгүй, хөшигний цаадах найруулагч болгохыг эрмэлздэг мэтээр нуруу

[1] Хүний дуулгаваргүй байдлыг ил болгохын тулд “сүйтгэл” гэдгийг ашиглажээ.

[2] “Хөмсөг зангидан, мянган хуруугаар чичлэн хүйтнээр үл ойшоохтой тулгарч, толгой гудайлган, номхон шар үхэр мэтээр хүмүүст үйлчилдэг” гэдэг нь анх нэг өгүүлбэр байсан боловч утгыг нь тодорхой болгохын тулд хоёр өгүүлбэрт хуваав. Өгүүлбэрийн эхний хэсэг нь хүний үйлдэлд хамаатай бол хоёр дахь нь Бурханы туулдаг зовлон болон Бурхан бол даруу, нуугдмал гэдгийг илтгэдэг.

[3] “Алагчлах сэтгэл” гэдэг нь хүмүүсийн дуулгаваргүй зан чанарыг хэлж байна.

[4] “Хэмжээгүй эрх эдлэх” хэмээсэн нь хүмүүсийн дуулгаваргүй зан чанарыг хэлжээ. Тэд өөрсдийгөө өргөмжилж, бусдыг дөнгөлөн, тэднийг дагуулж, өөрсдийнхөө төлөө зоводог. Тэд бол Бурханд дайсагнагч хүчин юм.

тэнэгэр зогсдог. Бурхан сүүлчийн эзэн хааны дүрд тоглож, ямар ч эрх чөлөөгүй утсан хүүхэлдэй[5] байх ёстой. Хүний үйл хэрэг хэлж ярихын аргагүй атал хүн яахаараа Бурханаас энэ тэрийг шаардах эрхтэй байдаг билээ? Хүн яахаараа Бурханд санал хэлэх эрхтэй байдаг билээ? Хүн яахаараа сул талыг нь өрөвд гэж Бурханаас шаардах эрхтэй байдаг юм бэ? Хүн Бурханаас өршөөл хүртэхэд яахан тохирох билээ? Бурханы уужим сэтгэлийг ахин дахин хүртэхэд яахан тэнцэх билээ? Бурханаас ахин дахин уучлал хүртэхэд яаж тэнцэх юм бэ? Хүний мөс чанар хаа байна? Бурханы сэтгэлийг хүн аль эрт шархлуулж, Бурханы зүрх сэтгэлийг аль эрт эмтэлсэн. Бурхан хүнийг Өөрт нь өгөөмөр зан гаргана, өчүүхэн ч болтугай халуун дулаан хандана гэж найдан нүдэндээ галтай, нүүрэндээ цогтойгоор хүмүүсийн дунд ирсэн юм. Гэвч Бурханы зүрх сэтгэлийг хүн тайтгаруулалгүй удаж, Бурханыг гагцхүү удаа дараа[6] дайрч давшлан, тарчилгасан. Зүрх сэтгэл нь хэт шунахай, хүсэл нь дэндүү их, хэзээ ч ханаж цаддаггүй, цаг ямагт зальхай, муйхар зоригтой байдаг хүн Бурханд ямар ч эрх чөлөө, үг хэлэх эрх огт олголгүйгээр доромжлолд өртөж, хүний эрхээр байхаас өөр сонголт үлдээдэггүй.

Бүтээлээс хойш өнөөг хүртэл Бурхан асар их зовлон туулж, маш олон дайралтад өртсөн. Гэвч хүн өнөөдөр ч Бурханд тавих шаардлагаа сулруулдаггүй, Бурханыг шинжиж, үл тэвчсэн хэвээр бөгөөд Бурхан буруу замаар орох вий, газар дээрх Бурхан хэрцгий, үндэслэлгүй авирлаж, үймээн дэгдээх вий, эсвэл юунд ч хүрч чадахгүй байх вий гэж гүнээ эмээх мэт Бурханд гагцхүү зөвлөгөө өгч, Түүнийг шүүмжилж, сахилгажуулдаг. Хүн Бурханд үргэлж ийнхүү ханддаг. Бурхан үүнд гуниглахаас өөр яалтай? Бурхан махбод болоод үлэмж их шаналал, доромжлол туулсан; гэтэл хүний сургаалыг Бурханаар хүлээн авхуулбал хэчнээн дор байх билээ? Бурхан хүмүүсийн дунд ирээд бүх эрх чөлөөгөө алдаж, Үхэгсдийн оронд хоригдсон мэт болчхоод хүний шинжилтийг өчүүхэн ч эсэргүүцэлгүй хүлээн авсан. Энэ нь ичгүүртэй бус уу? Хэвийн хүний гэр бүлд ирээд “Есүс” хамгийн их шударга бусыг амссан. Тоост энэ ертөнцөд ирээд хамгийн доод ёроолд нь хүртэл Өөрийгөө даруусгаж, туйлын эгэл махбодтой болсон нь бүр ч гутамшигтай. Хамгийн Дээд Бурхан шалихгүй хүн болоод зовлон бэрхшээл амсдаг бус уу? Бас Бурхан хүн төрөлхтний төлөө ингэдэг бус уу? Бурхан Өөрийгөө бодож байсан удаа бий юу? Иудейчүүд Өөрийг нь голж, амийг нь хөнөөж, хүмүүс даапаалан доог тохуу хийх үед Бурхан хэзээ ч Тэнгэрт гомдоллож, газар дэлхийд эсэргүүцэл илэрхийлээгүй. Өнөөдөр энэ олон мянган жилийн өмнөх эмгэнэлт явдал иудейчүүд шиг ийм хүмүүсийн дунд дахин гарч ирлээ. Тэд адилхан нүгэл үйлдэж байгаа бус уу? Хүн яахаараа Бурханы амлалтыг хүртэх эрхтэй байдаг юм бэ? Бурханыг эсэргүүцчихээд ерөөлийг нь хүртдэг бус уу? Хүн яагаад хэзээ ч шударга ёстой нүүр тулж, үнэнийг хайдаггүй юм бэ? Яагаад Бурханы хийдэг зүйлийг хэзээ ч сонирхдоггүй юм бэ?

---

[5] “Утсан хүүхэлдэй” гэдгээр Бурханыг мэддэггүй хүмүүсийг элэглэжээ.

[6] Хүмүүсийн дорд зан араншинг онцлохын тулд “удаа дараа” гэдгийг ашиглажээ.

Хүний зөв шударга байдал хаа байна? Хүний эрх тэгш байдал хаа байна? Хүн Бурханыг төлөөлөх зориг зүрхтэй юм гэж үү? Хүний шударга ёсны мэдрэмж хаа байна? Хүний хайрладаг хэр их зүйл Бурханы хайртай зүйл байдаг вэ? Хүн бяслаг, шохой хоёрыг ялгаж чаддаггүй,[7] хар цагааныг байнга хольж хутгадаг,[8] шударга ёс болон үнэнийг дарж, шударга бус, зөвт бус байдлыг өндөрт залдаг. Хүн гэрлийг үлдэн хөөж, харанхуйд харайн бүждэг. Үнэн болон шударга ёсыг эрж хайдаг хүмүүс харин ч гэрлийг үлдэн хөөж, Бурханыг эрж хайгсад Түүнийг улан дороо гишгэлээд, өөрсдийгөө тэнгэрт өргөн залдаг. Хүн дээрэмчнээс[9] өөрцгүй. Хүний эрүүл ухаан хаа байна? Зөв бурууг хэн ялгаж чадах вэ? Шударга ёсыг хэн баримталж чадах вэ? Үнэний төлөө зовоход хэн бэлэн байна? Хүмүүс харгис, хэрцгий! Бурханыг загалмайд цовдолчоод алга ташин уухайлж, зогсолтгүй уулгалан хашхичдаг. Тахиа нохой шиг тэд хуйвалдан хамсаж, өөрсдийн хаанчлалыг байгуулан, хөндлөнгийн оролцоо нь бүх газрыг түйвээсэн бөгөөд бүгд нэг газар бөөгнөрөөд нүдээ анин галзуу мэт ульсаар, хөл хөдөлгөөнтэй, золбоотой, бүдэг бадаг уур амьсгал түгж, бусдад харалганаар зүүгдэх хүмүүс бүгд өвөг дээдсийнхээ “цуутай” нэрсийг барин гарч ирсээр байдаг. Энэ тахиа, ноход Бурханыг аль эрт анхаарахаа больчоод, зүрх сэтгэлийнх нь байр байдалд хэзээ ч, ямар ч анхаарал хандуулаагүй. Бурхан хүнийг тахиа, нохойтой адилтган, зуун нохойг улиулахаар турхиран хуцаж буй нохой шиг гэж хэлдэгт гайхах юмгүй; ийм маягаар хүн Бурханы ажил ямар болохыг үл тоомсорлож, шударга ёс бий эсэх, Бурханд хөл тавих газар бий эсэхийг үл тоон, маргааш ямар байхыг үл хайхарч, өөрийн дорд, бузар булай байдлыг үл ойшоон ихээхэн шуугиан дэгдээсээр Бурханы ажлыг өнөөдөртэй золгууллаа. Хүн аливааг хэзээ ч төдийлөн их бодож байгаагүй, маргаашийн талаар хэзээ ч санаа зовоогүй, ашиг тустай, эрхэм нандин бүхнийг тэвэртээ цуглуулчхаад Бурханд үлдэгдэл, хаягдлаас[10] өөр юу ч үлдээгээгүй. Хүн төрөлхтөн хэчнээн харгис гээч! Хүн Бурханд огт санаа тавьдаггүй, бүх зүйлийг нь нууцхан залгичхаад Бурханыг ардаа хол хаян, оршин тогтнолд нь дахин огт анхаардаггүй. Хүн Бурханыг эдэлдэг атлаа эсэргүүцэж, уландаа гишгэдэг, харин амаараа Бурханд талархаж, магтдаг; Бурханд залбирч, найдахын хажуугаар Бурханыг хууран мэхэлдэг; Бурханы нэрийг “өргөмжилж”, Бурханы царай өөд харах атлаа улайм цайм, ичгүүр сонжуургүйгээр Бурханы сэнтийд суун, Бурханы “зөвт бус байдлыг” шүүдэг; Бурханд өртэй гэх үг амнаас нь гарч, Бурханы үгийг харах атлаа зүрх сэтгэлдээ Бурханыг хараж зүхдэг; хүн Бурханд “хүлээцтэй” ханддаг мөртөө дарлаж, аман дээрээ Бурханы төлөө ингэж байна гэдэг; гартаа Бурханы зүйлсийг барьж, амандаа Бурханы өгсөн хоолыг

---

[7] “Бяслаг, шохой хоёрыг ялгаж чаддаггүй” гэдэг нь Бурханы хүслийг хүмүүс сатанлаг зүйл болгон гуйвуулдгийг илтгэн, хүмүүс Бурханыг голдог зан араншинг ерөнхийд нь хэлжээ.

[8] Үнэнийг төөрөгдөлтэй, зөвт байдлыг ёрын муутай хольж хутгах явдлыг “хар цагааныг хольж хутгах” хэмээжээ.

[9] Хүмүүсийн мэдрэмжгүй, ойлголтгүй байдлыг “дээрэмчин” гэдгээр хэлжээ.

[10] Бурханыг хүмүүс дарладаг зан араншныг “үлдэгдэл, хаягдал” гэдгээр илтгэсэн болно.

зажилдаг ч Бурханыг бүхлээр нь залгихыг хүссэн мэт нүд нь хүйтэн цэвдэг, сэтгэл хөдлөлгүй байдлаар ширтдэг; хүн үнэнийг хардаг ч үүнийг Сатаны заль мэх гэж зүтгэдэг; шударга ёсыг хардаг ч үүнийг амь биеэ золиослох явдал болгохоор хүчилдэг; хүний үйл хэргийг хараад энэ нь Бурхан юу болох мөн гэж зүтгэдэг; хүний байгалиас заяасан авьяасыг хараад тэр бол үнэн гэж зүтгэдэг; Бурханы үйл хэргийг хараад ихэрхүү, биеэ тоосон байдал, сагсуу, өөрийгөө зөвтгөсөн байдал гэж зүтгэн, Бурханыг харчхаад хүн гэж нэрлэхээр оролдож, Сатантай хуйвалддаг бүтээгдсэн зүйлийн эгнээнд оруулахаар ихэд хичээдэг; Бурханы айлдвар гэдгийг нь хүн сайн мэддэг атлаа ердөө л хүний бичвэр гэж нэрлэнэ; махбодод Сүнс биеллээ олж, Бурхан махбод болсныг сайн мэддэг атлаа энэ махбод бол зүгээр л Сатаны үр удам гэж хэлдэг; Бурхан даруу, нууцлаг гэдгийг сайтар мэддэг атлаа Сатан шившиг болж, Бурхан ялсан гэхээс өөрийг хэлдэггүй. Яасан хэрэггүй амьтад вэ! Хүн хоточ нохой болж үйлчлэх ч үнэ цэнгүй! Тэрээр хар цагааныг ялгадаггүй, бүр харыг албаар цагаан болгон гуйвуулдаг. Хүний хүч, хүний бүслэлт Бурхан чөлөөлөгдөх өдрийг хүлцэж чадна гэж үү? Бурханыг албаар эсэргүүцсэнийхээ дараа хүн огт хайхардаггүй, тэр ч бүү хэл Бурханыг хөнөөхдөө тулж, Бурханд Өөрийгөө харуулах ямар ч боломж олгодоггүй. Зөвт байдал гэж хаана байна? Хайр хаана байна? Хүн Бурханы дэргэд суугаад, Түүнийг өвдөг сөгдүүлэн өршөөл гуйлгаж, өөрийн бүх зохион байгуулалтыг дуулгавартай дагуулж, бүх явуулгатайгаа үг дуугүй эвлэрүүлж, хийдэг бүхэндээ хүнээс дохио авахад Бурханыг хүргэж, эс бөгөөс унтуулцан[11], багтартлаа уурладаг. Харыг цагаан болгон гуйвуулдаг харанхуйн ийм нөлөөн дор Бурхан ганьхралд автахаас өөр яалтай? Бурхан санаа зовохоос өөр яалтай? Бурхан хамгийн сүүлийн үеийн ажлаа эхлэх үе нь тэнгэр газрыг бүтээх ажилтай адилхан байсан гэж яагаад хэлдэг вэ? Хүний үйл хэрэг тун “баялаг” бөгөөд “цаг ямагт ундрах амийн усны булаг” хүний зүрх сэтгэлийн талбайг тасралтгүй “дүүргэдэг” бол хүний “амийн усны булаг” Бурханы эсрэг эргэлзэх юмгүй[12] өрсөлддөг; энэ хоёр эвлэршгүй бөгөөд энэ нь ямар ч эрээ цээргүйгээр Бурханы оронд хүмүүсийг хангадаг байхад хүн холбогдох аюулыг огт бодолцолгүй үүнтэй хамтран ажилладаг. Тэгээд ямар үр дүнд хүрдэг вэ? Тэрээр Бурханыг цэвдгээр хойш тавин холдуулчхаад огт анхаарал хандуулдаггүй бөгөөд Бурхан анхаарлыг нь татах вий гэж асар их айн, Бурханы амийн усны булаг хүнийг уруу татаж, хүнийг олж авах вий гэж гүнээ эмээдэг. Иймээс хүн ертөнцийн асуудлыг олон жил туулсныхаа дараа Бурханы эсрэг хамсан хуйвалдаж, тэр ч бүү хэл Бурханыг хүнд шийтгэлийнхээ бай болгодог. Нүдэнд орсон хог мэтээр Бурханыг барьж аваад галд хийж цэвэршүүлэн, цэвэрлэе гэхээс байж яддаг. Бурханы тавгүйрхэхийг хараад хүн цээжээ дэлдэн инээж, баярласандаа бүжиж, Бурхан ч бас цэвэршүүлэлтэд уналаа

[11] Хүний хилэгнэж, бухимдсан үзэшгүй муухай царайг “унтуулцан” гэдгээр хэлжээ.

[12] Хүмүүсийн болчимгүй зан, Бурханыг өчүүхэн ч хүндэлдэггүй байдлыг “эргэлзэх юмгүй” гэдгээр хэлсэн болно.

гэцгээн, Бурханы бузар, ариун бус байдлыг шатаан цэвэрлэнэ гэж хэлэн, ингэх нь л үндэслэлтэй, ухаалаг, эдгээр нь л Тэнгэрийн шударга, боломжийн арга барил мэт байдаг. Хүний энэ зэрлэг ааш авир санаатай ч юм шиг, санаандгүй ч юм шиг. Хүн өөрийн үзэшгүй царай, муу муухай, бузар сүнс болон гуйлгачны хөөрхийлөлтэй төрхийг аль алийг нь илчилдэг; хаа сайгүй түйвээснийхээ дараа хөөрхийлөлтэй царайлж, Тэнгэрээс уучлал гуйн, туйлын өрөвдөлтэй бээжин хав шиг харагддаг. Хүн үргэлж тааварлахын аргагүй авирлаж, ямагт “бусдыг айлгахын тулд барын нуруун дээр сууж”,[a] үргэлж дүр үзүүлж, Бурханы зүрх сэтгэлийг өчүүхэн төдий ч үл бодолцон, өөрийн байр суурьтай ч огт харьцуулалт хийдэггүй. Бурхан өөрийг нь хилсдүүлсэн мэт, өөрт нь тэгж хандах учиргүй мэт, Тэнгэр харалган бөгөөд хүнд албаар төвөг учруулж байгаа мэт хүн зүгээр л Бурханыг чимээгүйхэн эсэргүүцдэг. Иймээс ямагт чимээгүйхэн хорлонт явуулга хийж, Бурханд тавьдаг шаардлагаа өчүүхэн ч багасгалгүй араатны нүдээр харж, Бурханы үйлдэл бүрийг ууртайгаар хялайн, өөрийгөө Бурханы дайсан гэж хэзээ ч үл бодож, Бурхан манангаас гараад аливааг тодорхой болгож, хүнийг “барын амнаас” аварч, гомдлыг нь тайлах өдөр ирнэ гэж найддаг. Эрин үеүдийн туршид маш олон хүний гүйцэтгэсэн Бурханыг эсэргүүцэх үүргийг өөрсдөө гүйцэтгэж байна гэж хүмүүс өнөөдөр ч боддоггүй; хийдэг бүхэндээ хүмүүс аль хэдийн төөрөлдөж, ойлгосон бүхнийг нь аль эрт далай тэнгис залгисан гэдгийг тэд яахан мэдэх билээ.

Үнэнийг ер нь хэн хүлээн зөвшөөрсөн юм бэ? Бурханыг хэн ер нь халуун дотноор угтсан юм бэ? Бурханы илрэлтийг хэн ер нь баяртайгаар хүсэн хүлээсэн юм бэ? Хүний зан араншин аль эрт доройтож, хүний бузарлал Бурханы сүмийг танигдахын аргагүй болгоод удлаа. Гэтэл хүн ажлаа үргэлжлүүлэн хийж, Бурханыг дорд үзсээр байдаг. Бурханыг эсэргүүцэх явдал нь чулуунд сийлэгдэн, өөрчлөх аргагүй болсон мэт аашлан, улмаар үг үйлдэлдээ дахин ад үзэгдэж байснаас хараагдахыг илүүд үздэг. Ийм хүмүүс яаж Бурханыг мэдэж чадах юм бэ? Тэд яахан Бурхантай хамт амарч чадах билээ? Мөн Бурханы өмнө очиход яаж тэнцэх юм бэ? Бурханы удирдлагын төлөвлөгөөнд өөрийгөө зориулахад мэдээж буруутах зүйл байхгүй ч хүмүүс юунд Бурханы ажил, бүрэн дүүрэн байдлыг ямагт ойшоож үзэлгүй, өөрсдийн цус, нулимсыг амь бие хайргүй зориулдаг юм бэ? Хүмүүсийн амь бие хайргүй зориулах сэтгэл нь эргэлзэх юмгүй эрхэм—гэвч тэдний нэхдэг “торго” Бурхан юу болохыг төлөөлөх ямар ч чадваргүй гэдгийг тэд яахан мэдэх билээ? Хүмүүсийн сайн санаа зорилго эргэлзэх юмгүй ховор, нандин—гэвч тэд “үнэлж баршгүй эрдэнэсийг”[13] яахан залгиж чадах билээ? Та нар дор бүрнээ өнгөрсөн үеэ эргэцүүлэн бодох хэрэгтэй: Та нар яагаад цэвдэг гэсгээлт, хараалаас огт

---

[a] Үүнийг эх бичвэр дэх “ху жиа ху вэй” хэмээх хятад хэлц үгэнд үндэслэн орчуулав. Энэ нь үнэг барын хамт алхан бусад амьтныг айлгаж, улмаар барын төрүүлдэг айдас, хүндлэлийг “зээлддэг” түүхтэй холбоотой. Хүмүүс өрөөлийн нэр төрийг “зээлдэн” бусдыг айлгаж, дарладаг явдлыг энэ зүйрлэлээр илтгэжээ.

[13] “Үнэлж баршгүй эрдэнэс” гэдэг нь Бурханы бүрэн дүүрэн байдлыг хэлж байна.

ангижирсангүй вэ? Хүмүүс яагаад сүр жавхлант үгс, зөвт шүүлттэй байнга ийм “ойр харилцаатай” байдаг юм бэ? Бурхан үнэхээр тэднийг шалгаж байгаа гэж үү? Бурхан тэднийг албаар цэвэршүүлж байгаа хэрэг үү? Цэвэршүүлэлт дунд хүмүүс яаж ордог вэ? Бурханы ажлыг тэд үнэхээр мэддэг үү? Бурханы ажил, өөрсдийн оролтоос хүмүүс ямар сургамж авсан юм бэ? Хүмүүс Бурханы захиасыг мартахгүй байх болтугай, мөн Бурханы ажлыг ойлгож, тодорхой олж тогтоон, өөрсдийн оролтыг зүй зохистойгоор удирдах болтугай.

АЖИЛ БА ОРОЛТ 10

Хүн төрөлхтөн өдий хүртэл ахиж дэвшсэн нь урьд өмнө тохиолдож байгаагүй нөхцөл байдал юм. Бурханы ажил, хүний оролт зэрэгцэн урагшилдаг тул Бурханы ажил ч бас зүйрлэшгүй гайхамшигт үйл явдал билээ. Өнөөдрийг хүртэлх хүний оролт бол урьд нь хүний хэзээ ч төсөөлж байгаагүй гайхамшиг юм. Бурханы ажил оргилдоо хүрч, улмаар хүний “оролт”[1] ч оргилдоо хүрлээ. Бурхан чадах чинээгээрээ Өөрийгөө дорд болгосон ба хүн төрөлхтөн, эсвэл орчлон ертөнц, бүх зүйлийн алийг нь ч огт эсэргүүцээгүй. Харин хүн Бурханы толгой дээр гарч, Бурханыг дарлах нь дээд цэгтээ хүрлээ; бүгд оргилдоо хүрч, зөвт байдлын өдөр болох цаг ирлээ. Газрыг дүнсгэр байдал бүрхэн, харанхуй бүх ард түмнийг нөмөрч байгааг юунд цааш үргэлжлүүлнэм? Бурхан хэдэн мянган жил, бүр олон түмэн жил ажиж, тэвчээр нь аль хэдийн туйлдаа хүрлээ. Хүн төрөлхтний хөдөлгөөн бүрийг Тэр ажиглан, хүний зөвт бус байдал хэчнээн удаан түйвээхийг ажиглаж ирсэн ч аль эрт хөшүүн болсон хүн юу ч мэдэрдэггүй. Тэгвэл Бурханы үйл хэргийг хэн ер нь ажсан юм бэ? Хэн харцаа дээш хандуулж, алсын бараа харав? Хэн чих тавин сонсов? Хэн ер нь Төгс Хүчитийн гарт байв? Хүмүүс бүгд хий хоосон айдаст автдаг.[2] Бухал өвс, дэрс ямар хэрэгтэй юм бэ? Тэд бие махбодтой болсон Бурханыг үхтэл нь тамлаж л чадна. Хэдийгээр тэд бухал өвс, дэрснээс цаашгүй ч “бүгдээс гаргууд”[3] хийдэг нэг зүйлтэй: тэр нь Бурханыг үхтэл нь тамлаад, дараа нь “хүмүүсийн зүрх сэтгэлийг энэ баясгадаг” гэж хашхирах явдал. Яасан нэмэргүй амьтад вэ! Гайхмаар нь, хүмүүсийн эцэс төгсгөлгүй урсгал дунд тэд анхаарлаа Бурханд хандуулж, Түүнийг нэвтэршгүй бүслэлтэд оруулдаг. Ааг омог нь улам бадран,[4] Бурханыг бүлэглэн

---

[1] Энд “хүний ‘оролт’” гэдэг нь хүний дуулгаваргүй зан араншинг илтгэж байна. Хүмүүс амь руу орох эрэг зүйлийг хэлэхээс илүүтэй тэдний сөрөг зан араншин, үйлдлийг энэ нь хэлдэг. Энэ нь Бурханыг эсэргүүцдэг хүний бүх үйлийг ерөнхийд нь хэлж байгаа болно.

[2] “Хий хоосон айдаст автдаг” гэдэг нь хүний хүн чанарын төөрөлдсөн амьдралыг егөөджээ. Энэ нь чөтгөрүүдтэй хамт амьдардаг хүн төрөлхтний амьдралын үзэшгүй муухай байдлыг хэлсэн болно.

[3] “Бүгдээс гаргууд” гэдгийг егөөдсөн байдлаар хэлжээ.

[4] “Ааг омог нь улам бадран” гэж егөөдөн хэлсэн бөгөөд энэ нь хүний үзэшгүй муухай байдлыг хэлдэг.

хүрээлж, алхам ч хөдөлж чадахааргүй болгодог. Тэд гартаа элдэв янзын зэвсэг бариад, дайснаа харж буй мэтээр Бурханыг харж, харц нь уур хилэнгээр дүүрэн байдаг; тэгээд “Бурханыг мөчилж хаяна” гэхээс тэсэж яддаг. Хэчнээн гайхмаар гээч! Хүн, Бурхан хоёр яагаад ийм эвлэршгүй дайснууд болчхов? Хамгаас хайр татам Бурхан болон хүний хооронд өшөө хорсол байгаа юм гэж үү? Бурханы үйлдэл хүнд ямар ч ашиг тусгүй юм гэж үү? Хүнийг хохироодог юм уу? Хүн далдичилгүй Бурханыг цоо ширтэж, бүслэлтийг нь Тэр сэтлэн, гуравдагч тэнгэр лүү буцаж очоод хүнийг дахин гянданд хийх вий гэхээс ихэд айдаг. Хүн Бурханаас сэрэмжлэн байж суух газраа олж яддаг бөгөөд алсад газар дээр эвхрэлдэн “автомат буу” бариад, хүмүүсийн дундах Бурхан руу онилдог. Өчүүхэн л хөдөлмөгц нь Бурханы хамаг бие, өмсөж зүүсэн бүхэн гээд бүх зүйлийг нь хүн газрын хөрснөөс арчин, юу ч үлдээхгүй мэт байдаг. Бурхан, хүн хоёрын харилцаа засаршгүй болжээ. Бурхан хүнд ойлгохын аргагүй байдаг; харин хүн албаар хараагүй дүр эсгэж, тэнэглэн, Миний оршин тогтнолыг огт харахыг хүсдэггүй, шүүлтийг минь уучилдаггүй. Иймээс хүнийг тааварлаагүй байх үед Би чимээгүйхэн хөвөн оддог бөгөөд хүнтэй хэн нь дээр, хэн нь доор болохоо харьцуулахаа болино. Хамгийн дорд “амьтан” болох хүн төрөлхтнийг Би цаашид анхаармааргүй байна. Би амар тайван оршин суудаг газартаа Өөрийн нигүүлслийг бүрэн дүүрнээр нь эргүүлэн аваачсан; хүн тун дуулгаваргүй тул Миний эрхэм нандин нигүүлслээс нэмж эдлэх ямар шалтгаан байх билээ? Өөрт минь дайсагнагч хүчинд Би нигүүлслээ хий дэмий хайрлахыг хүсдэггүй. Өөрийн нандин үр жимсийг Би дэврүүн тэмүүлэлтэй, эргэн ирэхэд минь халуунаар угтдаг Канааны тариаланчдад олгоно. Тэнгэр мөнх оршоосой, бас хамгийн гол нь хүн хэзээ ч бүү хөгшрөөсэй, тэнгэр хүн хоёр үүрд амраасай, Бурханыг мөнх ногоон “нарс, майлс” үүр дагаж, өв тэгш эрин үед хамтдаа орох үед тэнгэрүүдийг үүрд дагаасай гэж л Би хүсдэг.

Би хүнтэй олон өдөр хоногийг хамт өнгөрүүлж, дэлхий ертөнцөд хүнтэй хамт оршин суусан бөгөөд хүнд хэзээ ч нэмж шаардлага тавиагүй; харин хүнийг зүгээр л ямагт урагш замчилж, гагцхүү заан чиглүүлдэг бөгөөд хүн төрөлхтний хувь заяаны төлөө зохицуулалтын ажлаа зогсолтгүй гүйцэтгэдэг. Тэнгэрлэг Эцэгийн хүслийг хэн ер нь ойлгосон юм бэ? Тэнгэр газрын хооронд хэн зорчсон юм бэ? Би “өтөл насанд нь” дахин хүнтэй хамт баймааргүй байна, учир нь хүн хэт хуучинсаг үзэлтэй болохоор юу ч ойлгодоггүй; хүн Миний бэлдсэн зоог дээр гэдэс гарахаас өөрийг мэддэггүй бөгөөд бусад бүх зүйлээс хол хөндий байж, өөр ямар ч асуудлыг хэзээ ч бодолцдоггүй. Хүн төрөлхтөн хэт харамч, хүмүүсийн дунд дуу шуугиан, уй гуниг, аюул эрсдэл хэт их учраас эцсийн өдрүүдэд олж авсан ялалтын эрхэм нандин жимсээ Би хуваалцахыг хүсдэггүй. Хүн Намайг угтан авдаггүй тул өөрийн бүтээсэн баялаг ерөөлийг эдлэг—хүн төрөлхтөн рүү Би яалаа гэж хүчээр инээмсэглэх ёстой юм бэ? Ертөнцийн өнцөг булан бүрд халуун дулаан алга, дэлхий дэх байгалийн бүх өнгө үзэмжид хаврын өчүүхэн ч ул мөр алга. Учир нь хүн усны амьтан мэт өчүүхэн ч халуун дулаангүй, цогцос шиг бөгөөд судсаар нь лугших цус

хүртэл сэтгэл жиндээх хөлдүү мөс мэт. Халуун дулаан гэж хаана байна? Бурханыг хүн шалтгаангүйгээр загалмайд цовдлоод дараа нь өчүүхэн ч санаа зовоогүй. Хэн ч, хэзээ ч харамсаагүй бөгөөд энэ харгис дарангуйлагчид хүний Хүүг дахин нэг удаа “амьдаар нь барьж”[5], гал нээх багийн өмнө аваачин сэтгэл дэх үзэн ядалтдаа цэг тавихаар төлөвлөсөөр л байна. Ийм аюултай газарт үлдэх нь Надад ямар ашигтай юм бэ? Үлдвэл хүмүүст хямрал, хүчирхийлэл л авчирч, эцэс төгсгөлгүй төвөг удах болно, учир нь Би хүнд гагцхүү дайн л авчирч байсан болохоос амар амгаланг хэзээ ч авчирч байсангүй. Хүн төрөлхтний эцсийн өдрүүд дайнаар дүүрэн байх ёстой, хүний хүрэх газар хямрал, хүчирхийлэл дунд нуран унах ёстой. Би дайны “баяслаас” хуваалцах хүсэлгүй, мөн хүнийг цус урсган, золиос гаргахад нь дагахгүй, учир нь хүнд гологдоод “гуниг гутралд” автсан Надад хүний дайныг харах зориг зүрх алга—хүмүүс сэтгэлээ ханатал тулалдаг. Би амармаар байна, нойрсмоор байна; хүн төрөлхтөнд эцсийн өдрүүдэд нь чөтгөрүүд хань болог! Миний хүслийг хэн мэдэх вэ? Хүмүүс Намайг угтан авдаггүй, мөн хэзээ ч хүлээгээгүй тул хүнтэй Би гагцхүү салах ёс хийж, бие биеэ хүсэн хүлээх хайрын бэлэг болгон хүн төрөлхтөнд хүрэх газрыг нь хайрлаад, бүх эд баялгаа хүнд үлдээн, Өөрийн амийг хүмүүсийн дунд тарьж, хүний зүрх сэтгэлийн талбайд амийн үрээ суулган, хүнд мөнхийн дурсамж үлдээж, бүх хайраа өгөөд, Өөрт байгаа нандин бүхнийг олгохоос өөр яаж ч чадахгүй нь. Бид хоёр бие биеэ үүрд хайрласан ч болоосой, өчигдөр маань бидний бие биедээ өгдөг сайхан зүйл байсан ч болоосой, учир нь Би Өөрийгөө хүн төрөлхтөнд аль хэдийн бүрэн дүүрэн өгсөн атал хүнд ямар гомдол байж болох билээ? Би аль эрт амиа хүнд бүхэлд нь үлдээж, хүн төрөлхтөнд зориулан хайрын үзэсгэлэнт газрыг хагалахын тулд үг дуугүй шаргуу хөдөлмөрлөлөө; Би үүнтэй дүйцэх юуг ч хүнээс ер шаардаагүй, харин гагцхүү хүний зохицуулалтад захирагдаж, хүн төрөлхтөнд илүү сайхан маргаашийг бүтээхээс өөрийг хийгээгүй.

Бурханы ажил элбэг баян боловч хүний оролт маш их дутагдаж байна. Хүн, Бурхан хоёрын хамтын “аж ахуй” бараг бүгд Бурханы ажил; хүн хэр их орсон тухайд үзүүлэх зүйл бараг алга. Үгээгүй хоосон, харалган хүн бүр “эртний зэвсэг” гартаа барин өнөөдрийн Бурхантай хүч үздэг. Эдгээр “балар эртний бич” арайхийн цэх алхаж, “нүцгэн” биеэсээ огт ичдэггүй. Тэд Бурханы ажлыг үнэлэх ямар эрхтэй юм бэ? Дөрвөн мөчтэй эдгээр бичний олонхынх нь харц хилэнгээр дүүрч, гартаа эртний чулуун зэвсэг бариад Бурханы эсрэг тэмцэж, ертөнцөд урьд нь хэзээ ч үзэгдээгүй бичин хүний тулаан эхлүүлэх, бичин хүн, Бурханы хооронд газар даяар нэрд гарах эцсийн өдрүүдийн тэмцээн зохиохоор оролдож байна. Түүнчлэн энэ хагас босоо эртний бичин хүмүүсийн олонх нь маадгар зангаар бялхдаг. Нүүрийг нь бүрхсэн үс ширэлдээтэй, тэд алах санаа өвөртлөн урд хоёр хөлөө өргөдөг. Орчин цагийн хүн болж бүрэн хувьсах болоогүй тул зарим үед тэд цэх зогсож,

[5] “Амьдаар нь барих” гэдэг нь хүний балмад, жигшүүртэй зан араншинг хэлж байна. Хүн Бурханд зэрлэг балмад хандаж, өчүүхэн ч уучлал үл үзүүлэн, утгагүй шаардлага тавьдаг.

заримдаа мөлхөн, духанд нь хөлс бурзайж, хүсэл эрмэлзэл нь нүдэнд илхэн. Хариу тулалдах хүчгүй, цохилтоос арай ядан зайлж чадах лагс, удаан дөрвөн мөчтэй, тэдний хань хамсаатан болох онгон дагшин эртний бичин хүмүүсийн дөрвөн хөл дээрээ зогсохыг хараад тэд биеэ барьж ядна. Юу болоод өнгөрснийг харж амжихын завдалгүй, нүд ирмэхийн зуур дэвжээн дээрх “баатар” дөрвөн мөч нь дээш тэрийн газар ойчно. Ийм олон жил газар дээр буруу байрлаж байсан дөрвөн хөл нь гэнэт орвонгоороо эргэсэн бөгөөд бичин хүн цааш эсэргүүцэх ямар ч хүсэлгүй болдог. Энэ цаг үеэс хойш хамгийн эртний бичин хүн газрын хөрснөөс арчигддаг нь үнэхээр “эмгэнэлтэй”. Энэхүү эртний бичин хүн дэндүү гэнэтхэн амь үрэгдлээ. Хүний энэ гайхамшигт ертөнцөөс юунд ийнхүү яаран одов? Төлөвлөгөөнийхөө дараагийн алхмыг нөхөдтэйгөө юунд хэлэлцсэнгүй вэ? Бурхантай хүчээ үзэхийн нууцыг үлдээлгүй ертөнцөөс хагацсан нь яасан харамсалтай! Ийм өтөл бичин хүн “эртний соёл, урлагийг” үр удамдаа уламжлуулан үлдээхгүй, ганц ч үг ган хийлгүй үхсэн нь ямар бодлогогүй хэрэг вэ. Ойр дотнынхноо дэргэдээ дуудаж хайртай гэдгээ хэлэх цаг ч байсангүй, чулуун хавтан дээр ганц ч үг үл үлдээж, тэнгэрнарыг үл ялгаж, үгээр илэрхийлшгүй хүндрэл бэрхшээлийнхээ тухай юу ч хэлсэнгүй. Эцсийн амьсгал авахдаа үхэж буй биеийнхээ хажууд үр удмаа дуудаад, “дэвжээ рүү гарч Бурхантай бүү тэмцээрэй” гэж нүд анихынхаа өмнө хэлсэнгүй, дөрвөн мөч нь тэнгэр өөд ургасан модны мөчир адил үүрд дээш гозойно. Тэр бич гашуун үхлээр үхсэн мэт санагдана… Гэнэтхэн дэвжээний цаанаас түсхийн инээх дуулдаж, хагас босоо бичин хүмүүсийн нэг нь ухаан мэдрэлээ алджээ; хөгшин бичин хүнийхээс илүү хөгжсөн, буга юм уу бусад зэрлэг ан намнах зориулалттай “чулуун муна” барьсан тэрээр уур бухимдал дүүрэн, толгойдоо сайтар боловсруулсан төлөвлөгөөтэйгөөр[6] дэвжээн дээр үсрэн гардаг. Тэгээд гавьяа байгуулсан мэт байдаг. Чулуун мунынхаа “хүчийг” ашиглан “гурван минутын” туршид цэх зогсож чаддаг. Энэхүү гуравдагч “хөл” яасан агуу “бяртай” гээч! Бадируун, эв хавгүй, мунхаг хагас босоо бичин хүнийг гурван минутын турш цэх зогсоолоо—энэхүү хүндэт[7] хөгшин бичин хүн ийм эзэрхэг байгаад гайхах зүйл алга. Мэдээж хэрэг эртний чулуун зэвсэг “нэр төрийнхөө дайд хүрдэг”: Хутганы бариул, ир, үзүүр байвч ганц гэм нь ир нь гялалздаггүй—энэ хэчнээн энэлэнтэй. Бусад нь чадавхгүй дорд амьтад, өөрөө эрэлхэг баатар мэтээр дэвжээн дээр зогсоод, доор байх хүмүүсийг жигшсэн харцаар харах эрт үеийн “бяцхан баатрыг” дахин хар. Тэрээр зүрх сэтгэлдээ тайзны өмнөх хүмүүсийг чимээгүйхэн жигшдэг. “Улс орон хүндрэлд ороод байна, энэ дор бүрийн маань хариуцлага атал та нар юунд айж хулчийна вэ? Улс оронд гай гамшиг нүүрлэхийг хараад цус урсгасан тулаанд та нар оролцохгүй юм биш биз? Улс гай гамшгийн ирмэгт байхад яагаад та нар сэтгэл зовнихыг эн түрүүнд тавихгүй, зугаа

[6] “Толгойдоо сайтар боловсруулсан төлөвлөгөөтэй” гэж егөөдөн хэлсэн бөгөөд хүмүүс өөрсдийгөө мэддэггүй, биеийн бодит хэмжээгээ мэддэггүйг илтгэжээ. Энэ нь доромж үг юм.

[7] “Хүндэт” хэмээн егөөдөн хэлжээ.

цэнгэлийг адагт үлдээхгүй байна вэ? Улс орон дампуурч, ард түмэн доройтохыг та нар яаж харж тэвчинэ вэ? Үндэстнээ харийн эрхшээлд оруулах ичгүүрийг та нар үүрэхэд бэлэн гэж үү? Ямар гээч нэмэргүй амьтад вэ!" Ингэж бодох зуур нь тайзны өмнө зодоон үүсэж, бичин хүний нүд улам бүр уурсаж, дэлбэрэх[8] гэж байгаа мэт болдог. Бурханыг тулааны өмнө бүтэлгүйтээсэй гэхээс тэсэж ядан, Бурханыг хөнөөж хүмүүсийг баярлуулна гэхээс байж яддаг. Чулуун зэвсэг нь зохисон нэр алдартай ч гэлээ Бурханд хэзээ ч дайсагнаж чадахгүй гэдгээ тэр огт мэддэггүй. Биеэ хамгаалж, хэвтэж, босож амжаагүй байхад нь түүний хоёр нүд хараагүй болж, тэр урагш хойш ганхана. Тэгээд эртний өвөг дээдэс рүүгээ унаад дахин босдоггүй; эртний бичин хүнийг чанга тэврээд дахин орь дуу тавьдаггүй бөгөөд өөрийн дорой байдлыг хүлээн зөвшөөрч, эсэргүүцэх ямар ч хүсэлгүй болдог. Энэ хоёр хөөрхий бичин хүн дэвжээний өмнө насан эцэслэдэг. Өнөөдрийг хүртэл амьд явсан хүн төрөлхтний өвөг дээдэс зөвт байдлын Нар илэрсэн өдөр мэдлэггүйгээсээ үүдэн амь үрэгдсэн нь золгүй еэ! Олон мянган жил хүлээсэн бичин хүмүүс ерөөл хүртэх өдрөө өөрсдийн ерөөлийг диаволуудын хаантай хамт "эдлэхээр" Үхэгсдийн орон руу аваачиж, ийм агуу ерөөлийг алдан өнгөрөөсөн нь хэчнээн мунхаг хэрэг вэ! Амьдын ертөнц дэх энэ ерөөлийг хүү охидтойгоо эдлэхээр хадгалж яагаад болсонгүй вэ? Тэд гагцхүү өөрсдөдөө гай дуудаж байна! Багахан байр суурь, нэр хүнд, нэрэлхүү зангийн төлөө амь үрэгдэх золгүйтэлтэй учирч, тамын хаалгыг нээж, тамын хөвгүүд болохоор уралдаж байгаа нь юутай харамсалтай. Ийм төлөөс огт шаардлагагүй. "Үндэсний үзлээр тэгтлээ бялхаж явсан" эртний өвөг дээдэс "өөрсдөдөө тэгтлээ хатуурхаж, бусдад маш хүлцэнгүй хандаж", өөрсдийгөө тамд унаган, өнөөх чадваргүй дорд амьтдыг гадна үлдээсэн нь юутай харамсалтай. Ийм "ардын төлөөлөгчид" хаанаас олдох юм бэ? Тэд "үр хүүхдийнхээ сайн сайхны" төлөө, "ирээдүй хойч үеийн амар тайван амьдралын" төлөө Бурханы хөндлөнгийн оролцоог зөвшөөрдөггүй тул өөрсдийн амийг үл хайхардаг. Мөн "үндэстний төлөө" цааргагүйгээр өөрсдийгөө зориулж, Үхэгсдийн оронд үг дуугүй ордог. Ийм үндэсний үзлийг хаанаас олж болох вэ? Бурхантай тулалдаж байхдаа тэд үхэхээс ч, цус урсгахаас ч айдаггүй, маргаашийн төлөө бүр ч санаа зовдоггүй. Тэд зүгээр л тулааны талбарт гардаг. "Зориулах сэтгэлийнхээ" хариуд тэд гагцхүү мөнхийн гэмшилд автаж, мөнх дүрэлзэх тамын галд шатдаг нь хэчнээн хөөрхийлөлтэй!

Ямар сонирхолтой юм бэ! Бие махбодтой болсон Бурханыг хүмүүс яагаад байнга голж, хараан зүхэж ирсэн бэ? Бие махбодтой болсон Бурханы талаар хүмүүс яагаад ямар ч ойлголтгүй байдаг юм бэ? Бурхан буруу цаг үедээ ирсэн юм гэж үү? Бурхан буруу газар ирчихсэн юм гэж үү? Бурхан хүний "зөвшөөрсөн гэх гарын үсэггүйгээр" бие даан үйлдсэнээс үүдэн ийм зүйл тохиолдсон юм гэж үү? Хүний зөвшөөрөлгүйгээр Бурхан шийдвэр гаргаснаас болсон юм гэж үү? Бурхан

[8] "Дэлбэрэх" гэсэн нь Бурханд ялагдах үедээ уур бухимдлаар дүүрдэг хүмүүсийн үзэшгүй муухай төлөв байдлыг илтгэжээ. Энэ нь Бурханыг эсэргүүцдэг хэр хэмжээг нь илтгэдэг.

урьдчилан сануулга өгснийг баримтууд өгүүлдэг. Бурхан махбод болохдоо ямар ч буруу зүйл хийгээгүй—Тэр хүнээс зөвшөөрөл авах ёстой гэж үү? Түүнчлэн Бурхан хүнд аль эрт сануулсныг магадгүй хүмүүс мартчихсан бололтой. Хүн буруугүй, учир нь тэр аль эрт Сатаны завхралд өртөөд сүнсний ертөнцөд юу тохиож буй талаар байтугай тэнгэрийн дор өрнөж буй зүйлсийн талаар ч юу ч ойлгож чаддаггүй! Хүний өвөг дээдэс болох бичин хүн дэвжээн дээр амь үрэгдсэн нь тун харамсалтай хэдий ч гайхах зүйл биш: Тэнгэр, газар хоёр хэзээ ч нийцтэй байгаагүй атал усан толгойтой бичин хүн Бурханыг дахин махбод болно гэж сэтгэж яахан чадах билээ? “Жаран нас” хүрсэн ийм “хөгшин хүн” Бурхан илэрсэн өдөр насан эцэслэсэн нь хэчнээн гунигтай. Ийм агуу ерөөл ирэх үед ертөнцийг ерөөлгүй орхин одсон нь гайхалтай хэрэг бус уу? Бие махбодтой болсон Бурхан бүх шашин, давхаргыг донсолгож, шашны хүрээний анхдагч дэг журмыг “үймүүлж”, Бурхан илрэхийг хүсэн мөрөөсдөг бүх хүний зүрх сэтгэлийг донсолгосон. Дээдлэн хүндлэхгүй хэн байна? Бурхантай уулзах гэж хүсэн хүлээхгүй хэн байна? Хүмүүсийн дунд Бурхан олон жил биечлэн байсан ч хүн үүнийг хэзээ ч ухаараагүй. Өнөөдөр Бурхан Өөрөө гарч ирж, ялгамж чанараа олон түмэнд тунхагласан байхад яагаад энэ нь хүний зүрх сэтгэлд баясал авчирч үл чадав? Бурхан нэгэн цагт хүнтэй баяр гунигаа хуваалцсан бол өнөөдөр хүн төрөлхтөнтэй дахин уулзаад өнгөрч одсон цаг хугацааны шастирыг хуваалцдаг. Иудагаас явсных нь дараа хүмүүс Түүний ямар ч ул мөрийг олж чадаагүй. Бурхантай дахин нэг уулзах сан гэж хүсэн мөрөөсдөг тэд өнөөдөр Түүнтэй ахин нүүр учирч, дахин уулзсан гэдгээ огт мэддэггүй. Энэ нь өчигдрийг санагдуулахаас өөр яалтай? Хоёр мянган жилийн өмнөх энэ өдөр иудейчүүдийн үр удам болох Ионагийн хүү Симон Аврагч Есүсийг харж, Түүнтэй нэг ширээнд хооллож, Түүнийг олон жил дагасныхаа дараа улам их хайрлах болсон: Тэр Эзэн Есүсийг чин сэтгэлээсээ хайрлан, асар их хайртай байсан билээ. Жавартай тэжээлийн онгоцонд төрсөн алтан шаргал үстэй нярай нь бие махбодтой болсон Бурханы эхний дүр гэдгийг иудейчүүд огт мэдээгүй. Түүнийг өөрсөдтэйгөө адилхан гэж бүгд бодоцгоон, ялгаатай гэж хэн ч бодоогүй—энэхүү ердийн, эгэл Есүсийг хүмүүс яаж таньж чадах билээ? Иудейчүүд Түүнийг тухайн цаг үеийн иудей хүү гэж бодоцгоосон юм. Хэн ч Түүнийг хайр татам Бурхан гэж хараагүй бөгөөд хүмүүс Түүнд гагцхүү сохроор шаардлага тавьж, арвин баялаг ерөөл, амар амгалан, баяр баясал хайрлаач гэж хүссэн. Саятан мэт Түүнд хүний хүсэж болох бүх зүйл бий гэдгийг л тэд мэдэж байлаа. Гэвч хүмүүс Түүнд хэзээ ч хайр татам Нэгэн хэмээн хандаагүй; тэр үеийн хүмүүс Түүнийг хайрлаагүй, гагцхүү эсэргүүцэж, бодлогогүй шаардлага тавьсан. Есүс хэзээ ч эсэргүүцээгүй, харин Өөрийг нь мэдэхгүй байсан ч гэлээ хүнд цаг ямагт нигүүлсэл хайрласан юм. Тэр чимээгүйхнээр хүмүүст гагцхүү халуун дулаан, хайр, өршөөл хайрлан, хэрэгжүүлэх шинэ арга замыг өгч, хуулийн хүлээсээс хүнийг гаргасан. Хүн Түүнийг хайрлаагүй, гагцхүү Түүнд атаархаж, гойд авьяас билгийг нь таньсан. Хайр татам Аврагч Есүс хүн төрөлхтний дунд ирэх үедээ хэчнээн их доромжлол туулсныг харалган хүн төрөлхтөн яахан мэдэх билээ?

Түүний зовуурийг хэн ч бодолцож үзээгүй, Эцэг Бурханыг гэх хайрыг нь хэн ч мэдээгүй, Түүний ганцаардлыг хэн ч мэдэж чадаагүй; Мариа төрсөн эх нь хэдий ч өршөөлт Эзэн Есүсийн сэтгэл дэх бодлыг яахан мэдэх билээ? Хүний Хүүгийн туулсан үгээр илэрхийлшгүй зовлонг хэн мэдэх билээ? Хүмүүс хүсэлт тавьсныхаа дараа Түүнийг цэвдгээр үл ойшоон, гадагш хаясан. Иймээс Есүс өдрөөс өдөрт, жилээс жилд гудамжаар хэрэн хэсэж, олон жил тэнүүчилсээр урт атлаа ахархан гучин гурван хүнд бэрх жилийг өнгөрөөсөн юм. Хүмүүс хэрэгтэй үедээ инээмсэглэсэн царай гарган Түүнийг гэртээ урьж, шаардлага тавихаар оролддог байлаа—харин тус нэмрийг нь авсныхаа дараа хаалгаар даруй хөөн гаргадаг байв. Хүмүүс Түүний амнаас гарсан зүйлийг идэж, цусыг нь ууж, хайрласан нигүүлслийг нь эдэлсэн атлаа өөрсдөд нь хэн амь хайрласныг хэзээ ч мэддэггүй байснаасаа болж Түүнийг бас эсэргүүцсэн. Эцэст нь Есүсийг загалмайд цовдолсон ч Тэр ганц ч үг дуугараагүй. Өнөөдөр ч гэсэн Тэр чимээгүй л байна. Хүмүүс Түүний махыг идэж, цусыг ууж, өөрсдөд нь зориулан бэлддэг хоол хүнсийг нь идэцгээн, нээсэн замаар нь алхдаг атлаа Түүнийг голохоор санаархсан хэвээр байдаг; үнэндээ тэд өөрсдөд нь амь хайрласан Бурханд дайсан мэт хандаж, өөрсөд шиг нь боол хүмүүст тэнгэр Эцэг мэт ханддаг. Ингэснээрээ тэд Түүнийг албаар эсэргүүцдэг бус уу? Есүс хэрхэн загалмай дээр амь тавих болов? Та нар мэдэх үү? Өөрт нь хамгийн ойр дотно байсан, Өөрийг нь идэж, ууж, эдэлж байсан Иудас Түүнээс урваагүй гэж үү? Есүс шалихгүй, хэвийн багшаас цаашгүй байсан учраас Иудас урвасан бус уу? Есүс ер бусын, тэнгэрийн Нэгэн гэдгийг хүмүүс үнэхээр олж харсан бол хорин дөрвөн цагийн туршид загалмайд амьдаар нь цовдолж, эцэст нь Түүнийг амьсгал хураахад хүргэж яахан чадах билээ? Бурханыг хэн мэдэж чадах вэ? Хүмүүс гагцхүү ханаж цадашгүй шуналтайгаар Бурханыг эдэлдэг атлаа Түүнийг хэзээ ч мэддэг байгаагүй. Гар бариад бугуй барих хүмүүс “Есүсийг” тушаал, захирамждаа бүрэн дуулгавартай болгосон юм. Толгой тавих газаргүй хүний энэ Хүүд хэн ер нь өршөөнгүй байдлаар хандсан юм бэ? Эцэг Бурханы даалгаврыг биелүүлэхэд Түүнтэй хүч нэгтгэх талаар хэн ер нь бодолцсон юм бэ? Хэн ер нь Түүний талаар бодож үзсэн юм бэ? Хэн ер нь Түүний хүндрэл бэрхшээлийг хайхарч ирсэн юм бэ? Өчүүхэн ч хайргүйгээр хүн Түүнийг нааш цааш угзардаг; өөрийнх нь гэрэл, амь хаанаас ирснийг хүн мэддэггүй бөгөөд хүмүүсийн дунд шаналал туулсан хоёр мянган жилийн өмнөх “Есүсийг” яаж дахин нэг удаа цовдлохоо нууцхан төлөвлөхөөс өөр юу ч хийдэггүй. “Есүс” үнэхээр тийм их үзэн ядалт төрүүлдэг гэж үү? Түүний хийсэн бүхэн аль эрт мартагдсан гэж үү? Олон мянган жил хуримтлагдсан үзэн ядалт эцэст нь оргилон гарах болно. Иудейчүүдийн өрөөсөн дугуй та нар! “Есүс” та нарт хэзээ дайсагнасан болоод Түүнийг та нар тэгтлээ их үзэн ядах ёстой юм бэ? Тэр маш ихийг хийж, маш их үг хэлсний аль нь ч та нарт ашиг тус болоогүй юу? Хариуд нь юу ч нэхэлгүй амиа өгч, Өөрийгөө та нарт бүрэн дүүрэн өгсөн атал Түүнийг амьдаар нь барьж идэхийг хүссээр байгаа юм гэж үү? Тэр юугаа ч харамлалгүй, ертөнцийн алдар суу, хүмүүсийн дундах халуун дулаан,

хайр, бүх ерөөлийг эдлэлгүйгээр та нарт бүхнээ өгсөн. Хүмүүс Түүнд маш муухай ханддаг, газар дэлхийн бүх эд баялгийг хэзээ ч эдлээгүй, чин үнэнч, оргилуун зүрх сэтгэлээ хүнд бүрэн дүүрэн зориулдаг, Өөрийгөө хүн төрөлхтний төлөө бүрэн дүүрэн зориулсан Түүнд хэн ер нь халуун дулааныг өгөв? Хэн ер нь Түүнийг тайтгаруулав? Хүн Түүнд бүхий л дарамтыг өгч, хамаг золгүйтлээ Түүнд нялзаан, хүмүүсийн дундах хамгийн золгүй туршлагыг Түүнд тулгасан бөгөөд бүхий л шударга бус явдалд Түүнийг буруутгаж, үүнийг нь Тэр үг дуугүй хүлээн зөвшөөрсөн. Есүс ер нь хэн нэгэнд эсэргүүцэл илэрхийлсэн гэж үү? Хэн нэгнээс ер нь жаахан нөхөн төлбөр нэхсэн гэж үү? Хэн ер нь Түүнийг өрөвдөж үзсэн юм бэ? Хэвийн хүмүүс та нарын хэн нь хүүхэд насандаа хайраар дутаа вэ? Хэнд чинь өнгөлөг сайхан залуу нас байгаагүй вэ? Хэн чинь хайртай хүмүүсийнхээ халуун дулаанаар дутнам? Хэнд хамаатан садан, найз нөхдийн хайр үгүйлэгдэнэ вэ? Хэн бусдаас хүндлэл хүлээхгүй байна? Халуун дулаан гэр бүлгүй хэн байна? Итгэмжит хүний тайтгарлаар хэн дутнам? Гэтэл Есүс ер нь эдгээрийн аль нэгийг эдэлж байсан гэж үү? Хэн ер нь Түүнд багахан халуун дулааныг мэдрүүлсэн юм бэ? Хэн Түүнд өчүүхэн ч болов тайтгарал өгсөн юм бэ? Хэн ер нь Түүнд хүний багахан ёс суртахууныг харуулсан юм бэ? Хэн Түүнийг ер нь хүлцэж байсан юм бэ? Хүнд хэцүү цаг үед хэн ер нь Түүнтэй хамт байсан юм бэ? Хүнд хэцүү амьдралыг хэн ер нь Түүнтэй хамт өнгөрөөсөн юм бэ? Хүн Түүнд тавих шаардлагаа хэзээ ч сулруулаагүй; зүгээр л ямар ч эргэлзээгүйгээр шаардлага тавьдаг бөгөөд хүний ертөнцөд ирээд Тэр хүний шар үхэр, морь, хоригдол байж, хүнд бүхнээ өгөх ёстой мэт байдаг; эс бөгөөс хүн Түүнийг хэзээ ч уучлахгүй, Түүнд хэзээ ч зөөлөн хандахгүй, Түүнийг хэзээ ч Бурхан гэж дуудахгүй, мөн Түүнийг хэзээ ч сайнаар бодохгүй. Хүн Бурханы үхтэл нь шаналгахаар шийдсэн мэт Бурханд хэтэрхий хатуу ханддаг бөгөөд үхсэнийх нь дараа л Бурханд тавих шаардлагаа сулруулна; эс бөгөөс Бурханд тавих шаардлагынхаа стандартыг хэзээ ч бууруулахгүй. Ийм хүнийг Бурхан жигшихгүй байж яаж чадах юм бэ? Энэ нь өнөөдрийн эмгэнэл бус уу? Хүний мөс чанар хаана ч алга. Хүн Бурханы хайрыг хариулна гэж хэлсээр байгаа ч Бурханыг шинжиж, үхтэл нь тамладаг. Өвөг дээдсээс уламжилж ирсэн Бурханд итгэхийн “нууц жор” энэ бус уу? “Иудейчүүд” байхгүй газар гэж алга, өнөөдөр тэд өнөөх л ажлаа хийж, Бурханыг эсэргүүцэх нэг л ажлаа гүйцэлдүүлэх атлаа өөрсдөө Бурханыг дээдэлж байна гэж боддог. Хүн хоёр нүдээрээ Бурханыг таньж яахан чадах билээ? Махан биед амьдардаг хүн Бурханыг Сүнснээс ирсэн бие махбодтой болсон Бурхан хэмээн үзэж яахан чадах билээ? Хүмүүсийн дундаас хэн Түүнийг мэдэж чадах юм бэ? Хүмүүсийн дунд үнэн гэж хаана байна вэ? Жинхэнэ зөв шударга байдал хаана байна вэ? Бурханы зан чанарыг хэн мэдэж чадах вэ? Тэнгэр дэх Бурхантай хэн тэмцэж чадах вэ? Бурханыг хүмүүсийн дунд ирэхэд хэн ч мэдэлгүйгээр голсонд гайхах зүйл алга. Хүн Бурханы оршин тогтнолыг хүлцэж яахан чадах вэ? Ертөнцийн харанхуйг гэрэл үлдэн хөөхийг хүн яаж зөвшөөрөх билээ? Энэ бүхэнд хүн нэр төртэйгөөр зүтгэдэг бус уу? Энэ нь хүний

шулуун шударга оролт бус уу? Гэтэл Бурханы ажил хүний оролтод төвлөрдөг бус уу? Та нар Бурханы ажлыг хүний оролттой нэгтгэн Бурхан, хүн хоёрын хооронд сайн харилцаа тогтоож, хүний биелүүлэх учиртай үүргийг чадах чинээгээрээ биелүүлээсэй гэж Би хүсэж байна. Ийм маягаар дараа нь Бурханы ажил эцэслэж, Тэр алдар сууг олж авснаар төгсөх болно!

БУРХАНЫ АЖЛЫН ҮЗЭГДЭЛ 1

Иохан Есүсийн төлөө долоон жил ажиллаж, Есүсийг ирэх үед аль хэдийн зам зассан байв. Үүнээс өмнө, Иоханы тунхагласан тэнгэрийн хаанчлалын сайн мэдээ газар нутаг даяар сонсогдсон тул Иудей даяар түгж, хүн бүр түүнийг эш үзүүлэгч гэж нэрлэсэн юм. Тухайн үед Херод Хаан Иоханыг хөнөөхийг хүсэж байсан ч тэгж зүрхлээгүй, учир нь хүмүүс Иоханыг ихэд хүндэлдэг байсан бөгөөд хэрвээ Иоханыг хөнөөвөл тэд өөрийнх нь эсрэг босно гэдгээс Херод айжээ. Иоханы хийсэн ажил жирийн хүмүүсийн дунд үндэслэсэн ба тэрээр иудейчүүдэд хүндлэгдсэн юм. Есүс үйлчлэлээ гүйцэтгэж эхлэх үе хүртэл долоон жилийн туршид тэрээр Есүсийн замыг засжээ. Энэ шалтгааны улмаас Иохан бүх эш үзүүлэгчдээс хамгийн агуу нь байлаа. Иоханыг шоронд орсны дараа л Есүс албан ёсны ажлаа эхэлсэн юм. Иоханаас өмнө Бурханд зориулан зам зассан эш үзүүлэгч хэзээ ч байгаагүй, учир нь Есүсээс өмнө Бурхан хэзээ ч махбод болоогүй. Иймээс Иоханыг хүртэлх бүх эш үзүүлэгчээс Иохан л бие махбодтой болсон Бурханд зориулсан замыг засах цорын ганц хүн байсан бөгөөд ийм маягаар Иохан Хуучин болон Шинэ Гэрээний хамгийн агуу эш үзүүлэгч болжээ. Иохан Есүсийн баптисмаас долоон жилийн өмнө тэнгэрийн хаанчлалын тухай сайн мэдээг түгээж эхэлсэн юм. Түүний хийсэн ажил нь хүмүүст, Есүсийн хожим хийх ажлаас илүү дээгүүр мэт санагдсан ч тэрээр ердөө л эш үзүүлэгч байлаа. Тэр сүмийн дотор бус, харин үүний гаднах хот, тосгонд ажиллаж, үг хэлдэг байв. Тэр үүнийг мэдээж Иудейн ард түмний дунд, ялангуяа ядуу зүдүү хүмүүсийн дунд хийсэн юм. Иохан нийгмийн дээд зиндааны хүмүүстэй ховорхон уулзаж, зөвхөн Иудейн энгийн иргэдийн дунд сайн мэдээ түгээж байлаа. Энэ нь Эзэн Есүсийн төлөө зөв зохистой хүмүүсийг бэлтгэх, мөн ажиллахад тохиромжтой газрыг Түүнд зориулан бэлтгэхийн төлөө байв. Замыг нь засах Иохан мэтийн эш үзүүлэгч байсан тул Эзэн Есүс ирэнгүүтээ Өөрийн цовдлолын замыг шууд эхлүүлж чадсан юм. Бурхан ажлаа хийхээр махбод болох үедээ хүмүүсийг сонгох ажлыг хийх хэрэггүй байсан, мөн хүмүүсийг, эсвэл ажиллах газрыг биечлэн эрж хайх ч шаардлагагүй байв. Тэр ирэхдээ ийм ажил хийгээгүй; Түүнийг ирэхээс өмнө тохиромжтой хүн Түүний төлөө ийм зүйлийг аль хэдийн бэлдчихсэн байсан юм. Есүс Өөрийн ажлыг эхлэхээс өмнө Иохан энэ ажлыг аль хэдийн дуусгасан байлаа, учир нь бие махбодтой болсон Бурхан ажлаа хийхээр ирэх үедээ Өөрийг нь удаан хугацаанд хүлээж байсан хүмүүс дээр шууд ажилласан юм. Есүс, засаж залруулах

хүний ажлыг хийхээр ирээгүй. Тэр зөвхөн Өөрийн гүйцэтгэх үйлчлэлийг гүйцэтгэхээр ирсэн; өөр бусад зүйлс Түүнтэй ямар ч хамаагүй байлаа. Иохан ирэх үедээ Эзэн Есүсийн ажлын бай болгохын тулд сүмээс болон иудейчүүд дундаас тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн бүлэг хүмүүсийг гаргаж ирэх төдийг л хийсэн юм. Иохан долоон жилийн турш ажилласан, өөрөөр хэлбэл, тэрээр тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг долоон жилийн турш түгээсэн юм. Ажлынхаа үеэр Иохан олон гайхамшиг үзүүлээгүй, учир нь түүний ажил бол замыг засах явдал байсан; энэ нь бэлтгэл ажил байсан билээ. Бусад бүх ажил буюу Есүсийн хийх гэж байсан ажил түүнтэй хамаагүй байв; тэрбээр зөвхөн нүглээ улайж, гэмшихийг хүмүүсээс хүсэж, хүмүүст баптисм хүртээж байсан ба ингэснээр хүмүүс аврагдаж чадах байлаа. Хэдийгээр тэр шинэ ажил хийж, урьд нь хүний хэзээ ч алхаж байгаагүй замыг нээсэн боловч мөн л Есүст зориулан зам зассан юм. Тэр ердөө л бэлтгэл ажил хийсэн эш үзүүлэгч байсан бөгөөд Есүсийн ажлыг хийх чадваргүй байв. Есүс хэдийгээр тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг тунхаглах эхний хүн байгаагүй ч, мөн Иоханы эхлүүлсэн замаар үргэлжлүүлэн явсан ч Түүний ажлыг хийж чадах өөр хэн ч байгаагүй бөгөөд энэ нь Иоханы ажлаас илүү дээгүүр байсан юм. Есүс Өөрийн замыг бэлдэж чадаагүй; Түүний ажил шууд Бурханы өмнөөс хийгдсэн. Иймээс, Иохан хичнээн олон жил ажилласан нь хамаагүй, зүгээр л эш үзүүлэгч, ердөө л замыг зассан нэгэн хэвээр юм. Есүсийн хийсэн гурван жилийн ажил Иоханы долоон жилийн ажлаас давсан, учир нь Түүний ажлын мөн чанар адилхан байгаагүй. Есүс үйлчлэлээ гүйцэтгэж эхлэх үед буюу Иоханы ажил төгсөх үед Эзэн Есүсийн ашиглах хангалттай хүмүүс болон газруудыг Иохан бэлтгэсэн байсан бөгөөд тэдгээр нь Эзэн Есүс гурван жилийн ажлаа эхлэхэд хангалттай байв. Иймээс Иоханы ажил дуусангуут Эзэн Есүс Өөрийн ажлыг албан ёсоор эхэлж, Иоханы хэлсэн үг хаягдсан. Яагаад гэвэл, Иоханы хийсэн ажил зөвхөн шилжилт өөрчлөлтийн төлөө байсан бөгөөд түүний үг хүнийг шинэ өсөлтөд хөтлөх амийн үг байгаагүй; эцсийн эцэст түүний үг түр зуур хэрэглэгдсэн юм.

Есүсийн хийсэн ажил ер бусын байгаагүй; үүнд үйл явц байсан бөгөөд энэ бүхэн нь аливаа юмсын хэвийн хуулийн дагуу ахиж дэвшсэн. Амьдралынхаа сүүлчийн зургаан сард, энэ ажлыг хийхээр ирсэн гэдгээ Есүс гарцаагүй мэдэж байсан бөгөөд загалмайд цовдлогдохын тулд ирсэн гэдгээ мэдэж байв. Тэр Гетсемани цэцэрлэгт гурвантаа залбирсан шиг цовдлогдохоосоо өмнө Есүс Эцэг Бурханд тасралтгүй залбирсан юм. Баптисм хүртсэнийхээ дараа Есүс гурван жил хагасын хугацаанд Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэсэн бөгөөд албан ёсны ажил нь хоёр жил хагас үргэлжилжээ. Эхний жилд Түүнийг Сатан буруутгаж, хүн үймүүлсэн ба Тэрээр хүний сорилтод өртсөн юм. Тэр Өөрийн ажлыг гүйцэтгэх зуураа олон сорилтыг давж гарсан. Сүүлийн зургаан сард Есүсийг удалгүй цовдлогдох гэж байх үед Петрийн амнаас, Тэр бол амьд Бурханы Хүү, Тэр бол Христ гэх үг гарсан юм. Зөвхөн тэр үед л Түүний ажил бүгдэд мэдэгдэж, тэр үед л Түүний ялгамж чанар олон нийтэд илчлэгдсэн билээ. Түүний дараа Есүс, хүний төлөө цовдлогдоно,

тэгээд гурван өдрийн дараа дахин амилна; мөн Тэр золин авралын ажлыг биелүүлэхээр ирсэн ба Аврагч мөн гэдгээ шавь нартаа хэлсэн. Сүүлийн зургаан сард л Тэр Өөрийн ялгамж чанар болон хийхээр төлөвлөж буй ажлаа илчилсэн юм. Энэ нь бас Бурханы цаг үе байсан бөгөөд ажил ийнхүү хийгдэх байлаа. Тухайн үед Есүсийн ажлын нэг хэсэг нь Хуучин Гэрээний дагуу, түүнчлэн Хуулийн эрин үеийн Мосегийн хууль, Еховагийн үгийн дагуу байв. Есүс Өөрийн ажлын нэг хэсгийг хийхдээ энэ бүхнийг ашигласан юм. Тэрээр хүмүүст номлож, синагогт тэдэнд зааж сургаж, Өөртэй нь дайсагнадаг фарисайчуудыг зэмлэхийн тулд Хуучин Гэрээн дэх эш үзүүлэгчдийн зөгнөлийг хэрэглэж, тэдний дуулгаваргүй байдлыг илчилж, улмаар тэднийг яллахын тулд Бичвэрийн үгийг ашигласан. Учир нь тэд Есүсийн хийсэн зүйлийг үзэн ядсан; ялангуяа Есүсийн ажлын ихэнх нь Бичвэр дэх хуулийн дагуу байгаагүй, түүнчлэн Түүний зааж сургасан зүйл тэдний өөрсдийнх нь үгээс илүү өндөр, Бичвэр дэх эш үзүүлэгчдийн зөгнөсөн зүйлээс ч илүү дээгүүр байсан учраас тэд үзэн яджээ. Есүсийн ажил зөвхөн хүний золин аврал болон цовдлолын төлөө л байсан тул ямар нэгэн хүнийг байлдан дагуулахын тулд илүү их үг хэлэх хэрэггүй байсан юм. Хүмүүст Түүний заасан зүйлийн ихэнх нь Бичвэрийн үгээс гарсан бөгөөд Түүний ажил Бичвэрээс хэтрээгүй ч гэсэн, Тэрээр цовдлолын ажлыг гүйцэлдүүлж мөн л чадсан юм. Түүний ажил үгийн ажил байгаагүй, хүн төрөлхтнийг байлдан дагуулахын төлөө ч хийгдээгүй, харин хүн төрөлхтнийг золин аврахын төлөө хийгдсэн ажил билээ. Тэр зөвхөн хүн төрөлхтний төлөө нүглийн тахил болсон бөгөөд хүн төрөлхтний төлөөх үгийн эх сурвалж болоогүй. Тэрээр хүнийг байлдан дагуулах ажил болох Харь үндэстний ажлыг хийгээгүй, харин Бурхан байдаг гэдэгт итгэдэг хүмүүсийн дунд хийгдсэн цовдлолын ажлыг хийсэн юм. Хэдийгээр ажил нь Бичвэрийн суурин дээр хийгдэж, Тэрээр фарисайчуудыг яллахын тулд эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг ашигласан боловч энэ нь цовдлолын ажлыг гүйцэлдүүлэхэд хангалттай байв. Хэрвээ өнөөдрийн ажил мөн л Бичвэр дэх эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийн суурин дээр хийгдсэн бол та нарыг байлдан дагуулах боломжгүй байх байсан, учир нь Хуучин Гэрээнд Хятадын ард түмэн та нарын дуулгаваргүй байдал болон нүглийг тэмдэглээгүй байдаг ба та нарын нүглийн тухай ямар ч түүх байдаггүй. Иймээс хэрвээ энэ ажил мөн л Библид тулгуурласан бол та нар хэзээ ч буулт хийхгүй байсан. Библи нь израильчуудын хязгаарлагдмал түүхийг л тэмдэглэсэн байдаг бөгөөд сайн муу эсэхийг чинь тогтоох юм уу та нарыг шүүх чадваргүй. Би та нарыг израильчуудын түүхийн дагуу шүүх байлаа гээд төсөөлөөд үз—та нар Намайг өнөөдрийнх шигээ дагасаар байх байсан уу? Та нар хэчнээн хэцүү гэдгээ мэдэх үү? Энэ үе шатанд ямар ч үг хэлээгүй бол байлдан дагуулах ажлыг гүйцэлдүүлэх боломжгүй байх байв. Би загалмайд цовдлуулах гэж ирээгүй учраас та нарыг байлдан дагуулахын тулд Библиэс тусдаа үгийг хэлэх ёстой. Есүсийн хийсэн ажил Хуучин Гэрээнээс ердөө нэг үе шатаар өндөр байв; энэ нь эрин үеийг эхлүүлж, тэрхүү эрин үеийг удирдахад ашиглагдсан. Яагаад Тэр: “Би хуулийг хэрэгсэхгүй болгохын тулд биш, харин гүйцэлдүүлэхийн

тулд ирсэн” гэж хэлсэн бэ? Гэсэн ч Хуучин гэрээний израильчуудын хэрэгжүүлж байсан хууль болон даган мөрдөж байсан тушаалуудаас ялгаатай зүйл Түүний ажилд их байсан, учир нь Тэр хуулийг дуулгавартай дагахаар биш, харин гүйцэлдүүлэхээр ирсэн билээ. Үүнийг гүйцэлдүүлэх үйл явц нь олон бодитой зүйлсийг агуулж байсан: Түүний ажил илүү жинхэнэ, бодитой байсан, цаашлаад энэ нь илүү амьд агаад дүрэм журмыг сохроор баримтлах явдал биш байсан. Израильчууд Амралтын өдрийг сахиагүй гэж үү? Есүс ирэхдээ Амралтын өдрийг чанд мөрдөөгүй, учир нь Тэрээр, хүний Хүү бол Амралтын өдрийн Эзэн бөгөөд Амралтын өдрийн Эзэн ирэх үедээ хүссэнээрээ хийнэ гэж хэлсэн юм. Тэрээр Хуучин гэрээний хуулиудыг гүйцэлдүүлж, хуулийг өөрчлөхийн тулд ирсэн билээ. Өнөөдөр хийгддэг бүхэн өнөө үед үндэслэдэг ч Хуулийн эрин үе дэх Еховагийн ажлын суурин дээр тулгуурладаг бөгөөд энэ цар хүрээг давдаггүй. Жишээлбэл, хэлэх үгээ хянах, садар самуун үйлдэхгүй байх зэрэг нь Хуучин Гэрээний хууль биш гэж үү? Өнөөдөр та нараас шаарддаг зүйл зөвхөн Арван Тушаалаар хязгаарлагддаггүй, харин урьд байснаас илүү өндөр зэрэглэлийн тушаал болон хуулиас бүрддэг. Гэхдээ энэ нь урьдын зүйлсийг хэрэгсэхгүй болгоно гэсэн үг биш, учир нь Бурханы ажлын үе шат бүр урьд нь явагдсан үе шатны суурин дээр хийгддэг. Тахил өргөх, эцэг эхээ хүндлэх, хуурамч шүтээн шүтэхгүй байх, бусдыг дайрч доромжлохгүй, эсвэл хараахгүй байх, садар самуун үйлдэхгүй байх, тамхи татахгүй, архи уухгүй байх, үхсэн юм идэхгүй, цус уухгүй байх гэх мэт тухайн үед Еховагийн Израильд хийсэн ажлын тухайд бол, өнөөдөр ч гэсэн энэ нь хэрэгжүүлэлтийн чинь суурийг бүрдүүлдэггүй гэж үү? Өнгөрсөн үеийн суурин дээр л өнөөдрийг хүртэл ажил хийгдсээр ирсэн. Хэдийгээр өнгөрсөн үеийн хуулиудыг дурдахаа больж, чамд шинэ шаардлага тавьсан боловч эдгээр хууль хүчингүй болоогүйгээр үл барам, харин ч илүү өндөрт өргөгдсөн юм. Тэдгээрийг хүчингүй болгосон гэж хэлбэл өмнөх эрин үе хуучирсан гэсэн үг, гэхдээ зарим тушаалыг чи мөн л үүрд мөнхөд баримтлах ёстой. Өнгөрсөн үеийн тушаалууд аль хэдийн хэрэгжиж, аль хэдийн хүний оршихуй болсон бөгөөд “тамхи татаж болохгүй”, “архи ууж болохгүй” гэх мэт тушаалуудыг онцлон тэмдэглэх хэрэггүй. Энэ суурин дээр, өнөөдрийн хэрэгцээний чинь дагуу, биеийн хэмжээний чинь дагуу, өнөөдрийн ажлын дагуу шинэ тушаалуудыг гаргадаг. Шинэ эрин үеийн тушаалуудыг тунхаглах нь хуучин эрин үеийн тушаалуудыг хэрэгсэхгүй болгоно гэсэн үг биш, харин хүний үйлдлийг илүү бүрэн гүйцэд болгож, бодит байдалтай илүү зохицолтой болгохын тулд энэ суурин дээр тэдгээрийг илүү өндөрт өргөх явдал юм. Хэрвээ өнөөдөр та нараас израильчуудын адилаар зөвхөн Хуучин Гэрээний тушаалыг дагаж, хуулийг мөрдөхийг л шаардсан бол, тэр ч бүү хэл Еховагийн тогтоосон хуулийг цээжлэхийг шаардсан бол та нар өөрчлөгдөх ямар ч боломжгүй байх байлаа. Хэрвээ та нар тэр хэдхэн хязгаарлагдмал тушаалуудыг дагаж, эсвэл тоо томшгүй олон хууль цээжилсэн бол хуучин зан чанар чинь гүнзгий шингэсэн хэвээр үлдэх байсан бөгөөд үүнийг үндсээр нь арилгах ямар ч аргагүй байх байв. Тиймээс та нар улам бүр доройтох байсан бөгөөд та нарын нэг нь ч дуулгавартай болохгүй

байх байсан юм. Өөрөөр хэлбэл, хэдхэн энгийн тушаал, эсвэл тоймгүй олон хууль Еховагийн үйл хэргийг мэдэхэд чинь туслах чадваргүй. Та нар израильчуудтай адилхан биш: Хуулийг дагаж, тушаалыг цээжилснээр тэд Еховагийн үйл хэргийг нүдээр харж, өөрсдийн чин үнэнч байдлыг ганцхан Түүнд өгч чаддаг байсан. Харин та нар үүнд хүрч чадахгүй бөгөөд Хуучин Гэрээний эрин үеийн хэдхэн тушаал нь та нарыг зүрх сэтгэлээ өгөхөд хүргэх, эсвэл та нарыг хамгаалах чадваргүйгээр үл барам, харин ч та нарыг цалгар болгож, Үхэгсдийн орон руу унагана. Учир нь Миний ажил байлдан дагуулалтын ажил бөгөөд энэ нь та нарын дуулгаваргүй байдал болон хуучин зан чанар луу чиглэдэг. Ехова, Есүс хоёрын элдэг үг өнөөгийн шүүлтийн хатуу үгээс хавьгүй дутмаг байдаг. Тийм хатуу үггүйгээр, хэдэн мянган жилийн турш дуулгаваргүй байсаар ирсэн “мэргэжилтнүүд” та нарыг байлдан дагуулах боломжгүй юм. Хуучин Гэрээний хуулиуд нь та нарт нөлөөлөх хүчээ аль хэдийн алдсан ба өнөөдрийн шүүлт хуучин хуулиас хавьгүй илүү хатуу. Та нарт хамгийн тохиромжтой зүйл бол хуулийн шалихгүй хязгаарлалтууд биш, харин шүүлт юм, учир нь та нар хамгийн анхны хүн төрөлхтөн биш, харин хэдэн мянган жилийн турш ялзруулагдсан хүн төрөлхтөн билээ. Хүний одоо хүрэх ёстой зүйл өнөөдрийн хүний бодит байр байдлын дагуу, өнөө цагийн хүний хэв чанар болон бодит биеийн хэмжээний дагуу байдаг бөгөөд дүрэм журам баримтлахыг чамаас шаарддаггүй. Ингэснээр хуучин зан чанарт чинь өөрчлөлт гарч, чи өөрийн үзлийг хаяж болох юм. Тушаалууд бол дүрэм журам гэж чи бодож байна уу? Тэдгээрийг хүнд тавьдаг хэвийн шаардлага гэж хэлж болно. Тэдгээр нь чиний дагах ёстой дүрэм журам биш. Жишээ нь, тамхи татахыг хориглох явдлыг аваад үз—энэ нь дүрэм журам уу? Энэ нь дүрэм журам биш! Үүнийг хэвийн хүн чанар шаарддаг; энэ нь дүрэм журам биш, харин бүх хүн төрөлхтөнд тавьсан болзол билээ. Өнөөдөр тогтоосон арав гаруй тушаал ч бас дүрэм журам биш, харин хэвийн хүн чанарт хүрэхэд шаардагддаг зүйл юм. Хүмүүс өнгөрсөн үед тийм зүйлсийг эзэмшдэг, эсвэл мэддэг байгаагүй тул тэдгээрт хүрэхийг өнөөдөр хүмүүсээс шаарддаг бөгөөд ийм зүйлсийг дүрэм журам гэж тооцдоггүй. Хуулиуд нь дүрэм журамтай адилхан биш. Миний ярьж байгаа дүрэм журам нь ёслол, хэлбэрдэл, эсвэл хүний эндүү ташаа хэрэгжүүлэлтийг хэлдэг; эдгээр нь хүнд ямар ч нэмэргүй, ямар ч ач тусгүй зааврууд юм; эдгээр нь ямар ч утга учиргүй үйл ажиллагааг бий болгодог. Энэ нь стандарт дүрэм журам бөгөөд хүнд ямар ч ашиг тус өгдөггүй учир ийм дүрэм журмыг хаях учиртай. Хүнд ашиг тустай зүйлийг л хэрэгжүүлэх ёстой.

БУРХАНЫ АЖЛЫН ҮЗЭГДЭЛ 2

Нигүүлслийн эрин үед гэмшлийн сайн мэдээ тунхаглагдсан бөгөөд хүн итгэх л юм бол аврагдах байв. Өнөөдөр авралын оронд байлдан дагуулалт болон төгс болголтын тухай яриа л байдаг. Хэрвээ хүн итгэвэл бүхий л гэр бүлийнхэн нь

ерөөгдөнө, эсвэл нэг л аврагдсан бол үүрд аврагдсан гэж хэзээ ч хэлдэггүй. Өнөөдөр хэн ч эдгээр үгийг хэлдэггүй бөгөөд тийм зүйлс нь хоцрогдсон. Тухайн үед Есүсийн ажил бүх хүн төрөлхтнийг золин аврахын төлөө байв. Түүнд итгэсэн бүх хүний нүгэл уучлагдсан; Түүнд итгэдэг л бол Тэр чамайг золин аварна; хэрвээ Түүнд итгэсэн бол чи нүглийнх байхаа больж, нүглээсээ чөлөөлөгдөх байв. Аврагдах, итгэлээр зөвтгөгдөх гэдэг нь энэ юм. Гэхдээ итгэсэн хүмүүст ч Бурханыг эсэргүүцдэг, тэрслүү зүйл үлдсэн бөгөөд үүнийг мөн л аажмаар арилгах хэрэгтэй байлаа. Аврал гэдэг нь Есүс хүнийг бүрэн олж авсан гэсэн үг биш, харин хүн нүгэлтэн байхаа больж, нүглээ уучлуулсан гэсэн үг юм. Чи итгэх л юм бол дахиад хэзээ ч нүглийнх байхаа болих юм. Тухайн үед Есүс Өөрийнх нь шавь нарт үл ойлгогдох ихээхэн ажил хийж, хүмүүсийн ойлгоогүй зүйл ихийг хэлсэн. Учир нь тухайн үед Тэр ямар ч тайлбар өгөөгүй. Тиймээс Түүнийг явснаас хойш хэдэн жилийн дараа Матай Есүст зориулсан угийн бичгийг бүтээж, бусад нь ч бас хүний хүслээс гарсан ихээхэн ажил хийжээ. Есүс хүнийг төгс болгож, олж авахын төлөө ирээгүй, харин ажлын нэг үе шат буюу тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг авчирч, цовдлолын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд ирсэн юм. Иймээс Есүсийг цовдлогдмогц Түүний ажил бүрэн дууссан. Харин одоогийн үе шатанд—байлдан дагуулалтын ажилд—илүү олон үг хэлж, илүү их ажил хийх ёстой бөгөөд олон үйл явц байх ёстой. Иймээс Есүс, Ехова хоёрын ажлын нууц илчлэгдэх ёстой, ингэснээр бүх хүн итгэлээрээ илүү их ойлгож, тодорхой мэдэж авах болно, учир нь энэ бол эцсийн өдрүүдийн ажил бөгөөд эцсийн өдрүүд нь Бурханы ажлын төгсгөл, ажлын сүүлчийн цаг үе юм. Ажлын энэ үе шат нь чамд Еховагийн хууль болон Есүсийн золин авралыг тодорхой ойлгуулна, ингэснээр чи үндсэндээ Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний бүхий л ажлыг ойлгож, энэхүү зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний бүх ач холбогдол, мөн чанарыг ойлгож, Есүсийн хийсэн ажил, хэлсэн үг бүхний зорилгыг, тэр ч бүү хэл Библид сохроор итгэж, биширч байснаа ойлгож болох юм. Энэ бүхэн нь чамд нэгд нэггүй ойлгох боломж олгоно. Чи Есүсийн хийсэн ажил болон өнөөдрийн Бурханы ажлын аль алиныг ойлгож авна; чи бүх үнэн, амь, замыг ойлгож, нүдээр харна. Есүсийн хийсэн ажлын үе шатанд Есүс яагаад эцсийн ажлыг хийлгүй явсан бэ? Учир нь, Есүсийн ажлын үе шат нь эцсийн ажил байгаагүй. Түүнийг загалмайд цовдлох үед үг нь ч бас төгсгөл болсон; цовдлогдсоных нь дараа Түүний ажил бүрмөсөн дууссан. Одоогийн үе шат бол өөр: Үгийг дуустал хэлж, Бурханы бүх ажил гүйцэлдсэний дараа л Түүний ажил дууссан байх болно. Есүсийн ажлын үе шатанд хэлэлгүй үлдээсэн, эсвэл тодорхой илэрхийлээгүй олон үг байсан юм. Гэсэн ч Есүс юуг хэлсэн, юуг хэлээгүйгээ тоогоогүй, учир нь Түүний үйлчлэл бол үгийн үйлчлэл биш байсан бөгөөд загалмайд цовдлогдсоныхоо дараа Тэр явж одсон. Ажлын тэр үе шат нь ерөөсөө цовдлолын төлөө байсан бөгөөд одоогийн үе шаттай адилгүй. Ажлын энэ үе шат нь үндсэндээ төгсгөлийн төлөө, эмхэлж цэгцэлж, бүх ажлыг дуусгахын төлөө байдаг. Хэрвээ үгийг бүр дуустал нь хэлэхгүй бол энэхүү ажлыг

гүйцэлдүүлэх ямар ч аргагүй байх болно, учир нь ажлын энэ үе шатанд үгийг ашиглан бүх ажил төгсгөлдөө очиж, гүйцэлддэг. Тухайн үед Есүс хүмүүст үл ойлгогдох их ажил хийсэн. Тэрээр чимээгүй явж одсон бөгөөд өнөөдөр ч гэсэн Түүний үгийг ойлгодоггүй, ойлголт нь буруу ч зөв гэж итгэсээр байдаг, буруу гэдгээ ч мэддэггүй олон хүн байсаар байгаа. Эцсийн үе шат Бурханы ажлыг бүрэн төгсгөж, гүйцэлдүүлнэ. Бурханы удирдлагын төлөвлөгөөг бүгд ойлгож, мэдэж авна. Хүмүүсийн доторх үзэл, санаа зорилго, эндүү ташаа, утгагүй ойлголт, Ехова болон Есүсийн ажлын талаарх үзэл, Харь үндэстний тухай үзэл бодол болон бусад бүх алдаа, гажуудал засагдана. Тэгээд хүн амьдралын бүх зөв зам, Бурханы хийсэн бүх ажил, бүхий л үнэнийг ойлгоно. Тийм зүйл болох үед ажлын энэ үе шат төгсгөлдөө очно. Еховагийн ажил нь дэлхийг бүтээх явдал байсан бөгөөд энэ нь эхлэл байсан юм; ажлын энэ үе шат бол ажлын сүүлч бөгөөд төгсгөл юм. Эхэндээ Бурханы ажил Израилийн сонгогдсон хүмүүсийн дунд хийгдсэн бөгөөд энэ нь бүх газраас хамгийн ариун газар дахь шинэ эриний эхлэл байв. Ажлын сүүлчийн үе шат нь, дэлхийг шүүж, эрин үеийг төгсгөхийн тулд бүх улс орноос хамгийн бузар заваан оронд хийгддэг. Эхний үе шатанд Бурханы ажил хамгийн гэрэл гэгээтэй газар хийгдсэн бол сүүлчийн үе шат нь хамгийн харанхуй газарт хийгддэг бөгөөд энэхүү харанхуйг хөөн зайлуулж, гэрлийг авчирч, бүх хүнийг байлдан дагуулна. Бүх газраас хамгийн бузар заваан, харанхуй газрын ард түмэн байлдан дагуулагдаж, жинхэнэ Бурхан байдгийг бүх хүн ам хүлээн зөвшөөрч, хүн болгон бүрэн үнэмших үед бүхий л орчлон ертөнц даяар байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэхэд энэхүү баримтыг ашиглана. Ажлын энэ үе шат бэлгэдлийн чанартай: Энэ эрин үеийн ажил дуусмагц зургаан мянган жилийн удирдлагын ажил бүрмөсөн төгсөнө. Хамгийн харанхуй газарт байгаа хүмүүс байлдан дагуулагдмагц хаа сайгүй ийм зүйл болно гэдэг нь илэрхий юм. Ийм болохоор зөвхөн Хятад дахь байлдан дагуулалтын ажил л утга учиртай бэлгэдлийг агуулдаг. Хятад улс харанхуйн бүх хүчийг илтгэдэг бөгөөд Хятадын ард түмэн нь Сатан, махан бие, мах цуснаас бүтсэн бүх хүнийг төлөөлдөг. Хятадын ард түмнийг агуу улаан луу хамгийн их завхруулсан, тэд Бурханыг хамгийн хүчтэй эсэргүүцдэг бөгөөд хүн чанар нь хамгийн олиггүй, ариун бус тул бүх завхарсан хүн төрөлхтний төлөөлөгч билээ. Бусад улс оронд ямар ч асуудал байхгүй гэж хэлж байгаа юм биш; хүний үзэл бүгд адилхан бөгөөд эдгээр улс орны хүмүүс сайн хэв чанартай байж болох хэдий ч хэрвээ Бурханыг мэддэггүй бол Түүнийг эсэргүүцдэг байж таарна. Яагаад иудейчүүд ч бас Бурханыг эсэргүүцэж, сөрсөн бэ? Яагаад фарисайчууд ч бас Түүнийг эсэргүүцсэн бэ? Яагаад Иудас Есүсээс урвасан бэ? Тэр үед шавь нарынх нь олонх нь Есүсийг мэдээгүй. Есүсийг цовдлогдож, дахин амилсны дараа ч яагаад хүмүүс Түүнд итгээгүй вэ? Хүний дуулгаваргүй байдал бүгд адилхан бус уу? Зүгээр л Хятадын ард түмнийг жишээ болгож байгаа ба байлдан дагуулагдах үедээ тэд үлгэр дуурайл, загвар болж, бусдад лавлагаа болох болно. Та нар бол Миний удирдлагын төлөвлөгөөний хавсралт гэж Би яагаад үргэлж хэлдэг вэ? Учир нь Хятадын ард түмэнд завхрал,

бузар, шударга бус байдал, эсэргүүцэл, тэрслүү байдал хамгийн бүрэн дүүрэн илэрхийлэгдэж, янз бүрийн хэлбэрээрээ илчлэгддэг. Нэг талаас, тэд дорд хэв чанартай, нөгөө талаас, амьдрал, сэтгэлгээ нь хоцрогдмол, мөн зуршил, нийгмийн орчин, төрсөн гэр бүл нь бүгд ядуу дорд, хамгийн их хоцрогдсон байдаг. Тэдний байр суурь ч бас дорд. Энэ газарт хийж байгаа ажил бэлгэдлийн чанартай бөгөөд туршилтын энэ ажлыг бүхэлд нь хийж дуусгасны дараа Бурханы дараагийн ажил хавьгүй илүү амархан байх болно. Хэрвээ ажлын энэ үе шатыг дуусгаж чадвал дараагийн ажлыг хэлэхийн ч хэрэггүй. Ажлын энэ үе шат гүйцэлдвэл агуу амжилтад бүрэн хүрч, бүхий л орчлон ертөнц даяарх байлдан дагуулалтын ажил бүрмөсөн төгсөнө. Үнэндээ, та нарын дундах ажил амжилттай болмогц энэ нь бүх орчлон ертөнц даяарх амжилттай тэнцүү байх болно. Би та нарыг үлгэр жишээ, загвар болгосны ач холбогдол энэ юм. Тэрслүү байдал, эсэргүүцэл, бузар бохир байдал, шударга бус байдал—энэ бүхэн нь энэхүү хүмүүст байдаг бөгөөд тэдэнд байдаг зүйл хүн төрөлхтний бүх тэрслүү байдлыг төлөөлдөг. Тэд үнэхээр амаргүй. Тиймээс тэднийг байлдан дагуулалтын загвар болгодог ба байлдан дагуулагдмагцаа тэд аяндаа бусдын үлгэр жишээ, загвар болно. Израильд хийгдсэн эхний үе шат хамгийн их бэлгэдлийн чанартай байсан: Израильчууд хамгийн ариун, хамгийн бага завхарсан хүмүүс байсан тул энэ газар нутагт шинэ эринийг эхлүүлэх нь дээд зэргийн ач холбогдолтой байлаа. Хүн төрөлхтний өвөг дээдэс Израильд үүссэн ба Израиль бол Бурханы ажлын өлгий нутаг байсан гэж хэлж болно. Эхэндээ энэ хүмүүс хамгийн ариун байж, бүгд Еховаг шүтэн мөргөж байсан бөгөөд тэдэн дэх Бурханы ажил хамгийн их үр дүн гаргаж чадсан. Библи нь бүхэлдээ хоёр эрин үеийн ажлыг тэмдэглэсэн байдаг: Нэг нь Хуулийн эрин үеийн ажил, нөгөө нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан юм. Хуучин гэрээ нь израильчуудад хэлсэн Еховагийн үгийг болон Израиль дахь Түүний ажлыг тэмдэглэсэн байдаг; Шинэ гэрээ нь Иудей дахь Есүсийн ажлыг тэмдэглэсэн байдаг. Гэхдээ Библид яагаад ямар ч хятад нэр байдаггүй вэ? Бурханы ажлын эхний хоёр хэсэг Израильд хийгдсэн учраас, Израилийн хүмүүс сонгогдсон хүмүүс байсан учраас—өөрөөр хэлбэл, тэд Еховагийн ажлыг хүлээн авах эхний хүмүүс байлаа. Тэд хүн төрөлхтнөөс хамгийн бага завхарсан нь байсан бөгөөд эхэндээ Бурханыг дээдэлж, хүндлэх сэтгэлтэй байсан юм. Тэд Еховагийн үгийг дуулгавартай дагаж, үргэлж сүмд үйлчилж, тахилчийн өмсгөл юм уу титэм зүүдэг байв. Тэд Бурханыг шүтэн мөргөсөн хамгийн эртний хүмүүс, Түүний ажлын хамгийн эртний бай байлаа. Энэ хүмүүс бүх хүн төрөлхтний үлгэр дуурайл, загвар байв. Тэд бол ариун байдал, зөв шударга хүмүүсийн үлгэр дуурайл, загвар байсан юм. Иов, Абрахам, Лот, Петр, Тимот гэх мэтийн хүмүүс бүгд израильчууд байсан ба хамгийн ариун үлгэр дуурайл, загвар байлаа. Израиль нь хүн төрөлхтний дундаас Бурханыг шүтэн мөргөсөн хамгийн анхны улс орон байсан бөгөөд зөв шударга хүмүүс өөр хаанаас ч илүүтэйгээр эндээс төрөн гарчээ. Ирээдүйд бүх газар нутаг даяарх хүн төрөлхтнийг илүү сайн удирдахын тулд Бурхан тэдэн дээр ажилласан. Тэдний ололт амжилт,

Еховаг шүтэн мөргөсөн зөв шударга үйл хэрэг тэмдэглэгдсэн, ингэснээр тэд Нигүүлслийн эрин үед Израилиас цааших газар нутгийн хүмүүст үлгэр дуурайл, загвар болж чадах байв; тэдний үйлдэл өнөөдрийг хүртэл хэдэн мянган жилийн ажлыг хадгалсан юм.

Дэлхийг бүтээсний дараа Бурханы ажлын эхний үе шат Израильд хийгдсэн, тиймээс Израиль нь газар дээрх Бурханы ажлын төрсөн нутаг, газар дээрх Бурханы ажлын бааз байсан юм. Есүсийн ажлын цар хүрээ Иудейг бүхэлд нь хамарсан. Есүс Иудейн гадна ямар ч ажил хийгээгүй учраас Түүний ажлын үеэр Иудейн гаднах тун цөөхөн хүн энэ талаар мэдсэн юм. Өнөөдөр Бурханы ажлыг Хятадад авчирсан бөгөөд энэ нь гагцхүү энэ цар хүрээн дотор л хийгддэг. Энэ үед ямар ч ажил Хятадын гадна эхлээгүй; Хятадаас цааш түгэх явдал бол дараа нь хийгдэх ажил юм. Ажлын энэ үе шат Есүсийн ажлын үе шатнаас үргэлжлүүлэн явдаг. Есүс золин авралын ажил хийсэн бөгөөд энэ үе шат нь тэрхүү ажлаас үргэлжлэн хийгдэж байгаа ажил; золин авралын ажил гүйцэлдсэн бөгөөд энэ үе шатанд Ариун Сүнснээс үр тогтох хэрэггүй учир нь ажлын энэ үе шат өмнөх үе шаттай адилгүй, цаашлаад Хятад бол Израильтай адилгүй. Есүс золин авралын ажлын нэг үе шатыг гүйцэтгэсэн. Хүн Есүсийг харсан ба удалгүй Түүний ажил Харь үндэстнүүдэд түгэж эхэлсэн юм. Өнөөдөр Америк, Нэгдсэн Вант улс болон Орост Бурханд итгэдэг олон хүн байдаг, тэгвэл яагаад Хятадад, итгэдэг хүн цөөхөн байдаг юм бэ? Учир нь Хятад бол хамгийн хаалттай үндэстэн юм. Тийм болохоор Хятад орон Бурханы замыг хамгийн сүүлд хүлээн зөвшөөрсөн ба одоо ч гэсэн тэгснээс нь хойш зуу хүрэхгүй жил болж байна—энэ нь Америк болон Нэгдсэн Вант улсаас хавьгүй сүүлд болсон юм. Өөрийн ажлыг төгсгөхийн тулд, Өөрийн бүх ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Бурханы ажлын сүүлчийн үе шат Хятадын газар нутагт хийгдсэн. Израиль дахь хүмүүс бүгд Еховаг өөрсдийн Эзэн гэж дуудаж байсан. Тухайн үед тэд Түүнийг гэр бүлийнхээ тэргүүн нь гэж үзэж байсан бөгөөд бүхий л Израиль нь, хүн бүхэн өөрсдийн Эзэн Еховаг шүтэн биширсэн асар том гэр бүл болсон юм. Еховагийн Сүнс тэдэнд үргэлж харагдаж, тэдэнтэй ярилцаж, Өөрийн дуу хоолойг айлдсан бөгөөд тэдний амьдралыг залж чиглүүлэхийн тулд үүлэн багана болон дуу чимээг ашигласан. Тухайн үед Сүнс Өөрийн удирдамжийг Израильд шууд өгч, Өөрийн дуу хоолойгоор хүмүүстэй ярьж, айлдаж байсан бөгөөд тэд үүл харж, аянгын нүргээнийг сонссон, ийм маягаар Тэр тэдний амьдралыг хэдэн мянган жилийн турш залж чиглүүлсэн юм. Тиймээс Израилийн ард түмэн л Еховад үргэлж шүтэн мөргөсөн. Ехова бол тэдний Бурхан бөгөөд Харь үндэстнүүдийн Бурхан биш гэж тэд итгэдэг. Энэ нь гайхмаар зүйл биш: эцсийн эцэст Ехова тэдний дунд бараг 4,000 жилийн турш ажилласан. Хятадын газар нутагт хэдэн мянган жилийн турш үхсэн мэт унтсаныхаа дараа, тэнгэр газар, бүх зүйл аяндаа бий болоогүй, харин Бүтээгч бүтээсэн гэдгийг доройтмол хүмүүс одоо л мэдэж эхэлсэн. Энэхүү сайн мэдээ хилийн чанадаас ирсэн учраас энэ сайн мэдээг хүлээн зөвшөөрдөг бүх хүн тэрслүү бөгөөд тэд бол өөрсдийнхөө өвөг

дээдэс болох Буддагаас урвасан өөдгүй амьтад гэж феодалын эсэргүү үзэлтнүүд итгэдэг. Түүнчлэн, эдгээр феодалын үзэл санаатай хүмүүсийн олонх нь: “Хятад хүмүүс яаж гадныхны Бурханд итгэж болох юм бэ? Тэд өвөг дээдсээсээ урваж байгаа бус уу? Тэд мууг үйлдэж байгаа бус уу?” гэж асуудаг. Ехова бол өөрсдийнх нь Бурхан гэдгийг өнөөдөр хүмүүс аль хэдийн мартчихсан. Тэд Бүтээгчийг аль эрт умартсан бөгөөд оронд нь, хүн бичнээс үүссэн ба байгаль ертөнц жамаараа бий болсон гэх утгатай хувьслын онолд итгэдэг. Мөн хүн төрөлхтний эдэлж хэрэглэдэг сайн хоол хүнсийг бүгдийг нь байгаль хангадаг, хүний амьдрал, үхэлд дэг журам байдаг бөгөөд энэ бүхнийг захирдаг Бурхан оршин байдаггүй гэж итгэдэг. Түүнчлэн, Бурхан бүх зүйлийг захирдаг гэдэг нь мухар сүсэг бөгөөд шинжлэх ухааны биш гэж хэлдэг бурхангүй үзэлтнүүд олон бий. Гэхдээ шинжлэх ухаан Бурханы ажлыг орлож чадах уу? Шинжлэх ухаан хүн төрөлхтнийг захирч чадах уу? Бурхангүй үзэлд захирагддаг улс оронд сайн мэдээ тунхаглах нь амаргүй ажил бөгөөд асар их саад бартаа агуулдаг. Өнөөдөр ийм маягаар Бурханыг эсэргүүцдэг хүмүүс олон байгаа бус уу?

Есүсийг ажлаа хийхээр ирэх үед олон хүн Түүний ажлыг Еховагийн ажилтай харьцуулж, нийцэлгүй зүйл олоод Есүсийг загалмайд цовдолсон. Тэд яагаад Тэдний ажлаас ямар ч нийцэл олоогүй вэ? Нэг талаараа энэ нь Есүс шинэ ажил хийснээс болсон, бас Есүсийг ажлаа эхлэхээс өмнө хэн ч Түүний угийн бичгийг бичээгүй байснаас болсон. Хэн нэгэн бичсэн бол сайн байх байсан—тэгсэн бол хэн Есүсийг загалмайд цовдлох юм бэ? Хэрвээ Матай хэдэн арван жилийн өмнө Есүсийн угийн бичгийг бичсэн бол Есүс тийм их хавчлага амсахгүй байх байсан юм. Тийм биз дээ? Есүсийн угийн бичгийг—Тэр бол Абрахамын хүү, мөн Давидын удам—гэдгийг уншмагцаа хүмүүс Түүнийг хяхан хавчихаа болих байв. Түүний угийн бичгийг хэтэрхий орой бичсэн нь харамсалтай биш гэж үү? Харамсалтай зүйл юу вэ гэхээр Библи Бурханы ажлын хоёр үе шатыг л тэмдэглэсэн байдаг: нэг үе шат нь Хуулийн эрин үеийн ажил, нөгөө нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан; нэг үе шат нь Еховагийн ажил, нөгөө нь Есүсийн ажил байсан. Хэрвээ агуу эш үзүүлэгч өнөөдрийн ажлыг зөгнөчихсөн байсан бол хэчнээн сайн байх сан билээ. Библид “Эцсийн өдрүүдийн ажил” гэсэн гарчигтай нэмэлт хэсэг байсан бол—тэр нь хавьгүй дээр байх байсан бус уу? Яагаад хүн өнөөдөр маш их зовлон бэрхшээлд өртөх ёстой юм бэ? Та нар үнэхээр хүнд хэцүү үеийг туулсан! Хэрвээ хэн нэгэн үзэн ядуулах учиртай бол эцсийн өдрүүдийн ажлыг зөгнөөгүйнхээ төлөө Исаиа, Даниел хоёр, хэн нэгэн буруутгагдах ёстой бол хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханы угийн бичгийг арай эрт жагсаан бичээгүй Шинэ гэрээний элч нар байдаг. Ямар ичгүүртэй хэрэг вэ! Та нар хаа сайгүй нотлох баримт хайх хэрэгтэй бөгөөд үгийн жаахан хэлтэрхий олсныхоо дараа ч тэдгээр нь үнэхээр нотолгоо мөн эсэхийг таньж чаддаггүй. Ямар ичмээр юм бэ! Бурхан Өөрийнхөө ажилд яагаад ийм нууцлаг байдаг юм бэ? Өнөөдөр олон хүн нотлох баримт хараахан олоогүй ч бас үүнийг үгүйсгэж чаддаггүй. Тэгвэл тэд юу хийх ёстой вэ? Тэд Бурханыг

шийдэмгийгээр дагаж чаддаггүй, гэхдээ бас тийм эргэлзээтэйгээр урагш явж ч чаддаггүй. Иймээс олон “ухаалаг, авьяастай эрдэмтэн” Бурханыг дагах үедээ “оролдоод үзэх” хандлага өвөрлөдөг. Энэ нь хэтэрхий төвөгтэй! Хэрвээ Матай, Марк, Лук, Иохан нар ирээдүйг зөгнөж чаддаг байсан бол юмс хавьгүй илүү амархан байх байсан бус уу? Иохан хаанчлал дахь амьдралын дотоод үнэнийг харсан бол илүү дээр байх байв—тэр зөвхөн үзэгдэл хараад, газар дээрх бодитой материаллаг ажлыг хараагүй нь хэчнээн харамсалтай билээ! Үнэхээр өрөвдөлтэй! Бурхан яачихаа вэ? Түүний ажил Израильд маш сайн явагдсаны дараа яагаад одоо Хятадад ирсэн юм бэ, бас яагаад махбод болж, хүмүүсийн дунд биечлэн ажиллаж, амьдрах хэрэгтэй болсон юм бэ? Бурхан үнэхээр хүнийг хайхардаггүй! Тэр хүмүүст урьдчилан хэлээгүйгээр үл барам, Өөрийн гэсгээлт, шүүлтийг гэнэтхэн авчирсан. Үнэхээр ойлгохын аргагүй! Бурхан анх махбод болохдоо бүх дотоод үнэнийг хүнд урьдчилан хэлээгүйнхээ улмаас ихээхэн бэрхшээл амссан. Тэр үүнийг мартсан байж таарахгүй биз дээ? Тэгвэл Тэр яагаад энэ удаа хүнд бас л хэлдэггүй юм бэ? Өнөөдөр Библид зөвхөн жаран зургаан ном байдаг нь хэчнээн золгүй хэрэг билээ дээ. Эцсийн өдрүүдийн ажлыг зөгнөсөн дахиад ганцхан ном хэрэгтэй байсан юм! Чи тэгж бодохгүй байна уу? Ехова, Исаиа, Давид нар ч өнөөдрийн ажлыг огт дурдаагүй. Тэд 4,000 орчим жилээр тусгаарлагдан өнөө үеэс улам цааш холдсон. Есүс ч гэсэн өнөөдрийн ажлыг бүрэн зөгнөөгүй, энэ талаар бага зэрэг л ярьсан бөгөөд хүн мөн л хангалтгүй нотолгоо олдог. Хэрвээ чи өнөөдрийн ажлыг өмнөхтэй харьцуулбал энэ хоёр бие биетэйгээ хэрхэн таарч тохирдог вэ? Еховагийн ажлын үе шат Израиль руу чиглэж байсан, иймээс хэрвээ чи өнөөдрийн ажлыг үүнтэй харьцуулбал үл нийцэл бүр ч их байх болно; энэ хоёрыг ердөө харьцуулах аргагүй. Чи Израиль эсвэл Иудейнх биш; хэв чанар болон бүх зүйл чинь дутуу дулимаг—чи яаж өөрийгөө тэдэнтэй харьцуулж болох юм бэ? Энэ нь боломжтой юу? Өнөөдөр бол Хаанчлалын эрин үе гэдгийг мэдэж ав, энэ нь Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеэс өөр. Ямар ч тохиолдолд томьёо хэрэглэхээр бүү оролд; Бурханыг тийм ямар ч томьёоноос олж чадахгүй.

Есүс төрснөөсөө хойших 29 жилийн хугацаанд хэрхэн амьдарсан бэ? Түүний хүүхэд нас болон залуу насны талаар Библид юу ч тэмдэглээгүй байдаг; тэдгээр нь ямархуу байсныг чи мэдэх үү? Түүнд ямар ч хүүхэд нас, эсвэл залуу нас гэж байгаагүй ба төрөх үедээ л Тэр аль хэдийн 30 настай байсан байж болох уу? Чи дэндүү багыг мэддэг, иймээс өөрийн үзэл бодлоо хэлэхдээ хайхрамжгүй бүү бай. Энэ нь чамд ямар ч сайн зүйл болохгүй! Есүс 30 насныхаа төрсөн өдрөөс өмнө баптисм хүртэж, диаволын сорилтыг амсахын тулд цөл рүү Ариун Сүнсээр удирдуулсан гэдгийг л Библи тэмдэглэсэн байдаг. Мөн Дөрвөн Сайн мэдээ нь Түүний гурван жил хагасын ажлыг тэмдэглэсэн байдаг. Түүний хүүхэд нас болон залуу насны талаар ямар ч тэмдэглэл байдаггүй боловч Түүнд хүүхэд нас, залуу нас байгаагүй гэдгийг энэ нь нотолдоггүй; зүгээр л анх Тэр ямар ч ажил хийгээгүй бөгөөд хэвийн хүн байсан юм. Тэгвэл, Есүс залуу нас, эсвэл хүүхэд насгүйгээр 33

жил амьдарсан гэж та нар хэлэх үү? Тэр гэнэтхэн гучин гурван нас хагастай болсон байж болох уу? Түүний талаар хүний боддог бүхэн ер бусын, бодит бус байдаг. Бие махбодтой болсон Бурхан эгэл, хэвийн хүн чанарыг эзэмшдэг нь эргэлзээгүй боловч ажлаа хийхдээ бүрэн бус хүн чанар болон бүрэн бурханлаг чанараар шууд хийдэг. Үүний улмаас хүмүүс өнөөдрийн ажлын талаар, бүр Есүсийн ажлын талаар ч эргэлзээ өвөрлөдөг. Бурханы ажил хэдийгээр махбод болсон хоёр удаадаа ялгаатай байдаг боловч Түүний мөн чанар адилхан. Мэдээж хэрвээ чи Дөрвөн Сайн мэдээний тэмдэглэлийг унших юм бол ялгаа нь бүр их. Есүсийн хүүхэд нас болон залуу насны амьдралыг чи хэрхэн эргэн санах вэ? Чи Есүсийн хэвийн хүн чанарыг хэрхэн ойлгох вэ? Магадгүй чи өнөөдрийн Бурханы хүн чанарын талаар хүчтэй ойлголттой байж болох ч Есүсийн хүн чанарыг ухаардаггүй, тэр ч бүү хэл, үүнийг ойлгодоггүй. Хэрвээ Матай тэмдэглээгүй бол чамд Есүсийн хүн чанарын талаар ямар ч таамаг байхгүй байх байсан юм. Магадгүй Намайг Есүсийн амьдралын түүхийг ярьж, Есүсийн бага нас болон залуу насны дотоод үнэнийг хэлэх юм бол чи толгой сэгсрэн: “Үгүй! Тэр тийм байж таарахгүй. Түүнд ямар нэгэн сул тал байх учиргүй, тэр ч байтугай, ямар нэгэн хүн чанар байх ёсгүй!” гэж хэлнэ. Чи бүр орилж, хашхирна. Чи Есүсийг ойлгодоггүй учраас л Миний талаар үзэлтэй байдаг. Есүс бол дэндүү бурханлаг, Түүнд бие махбодын юу ч байхгүй гэж чи итгэдэг. Гэхдээ баримт бол баримт хэвээр юм. Үнэн баримтуудыг үл хэрэгсэн ярихыг хэн ч хүсдэггүй, учир нь Намайг ярих үед энэ нь үнэнтэй холбоотой байдаг; энэ нь таамаглал ч биш, зөгнөл ч биш. Бурхан агуу өндөрт өгсөж чадна, түүнчлэн агуу гүнд нуугдаж чадна гэдгийг мэдэж ав. Тэр бол санаанаасаа зохиодог зүйл чинь биш—Тэрээр тодорхой нэг хүний бодож олсон хувийн Бурхан биш, бүх бүтээлийн Бурхан билээ.

БУРХАНЫ АЖЛЫН ҮЗЭГДЭЛ 3

Бурхан анх махбод болохдоо Ариун Сүнснээс олдсон бөгөөд энэ нь Түүний хийхээр зорьсон ажилтай холбоотой байлаа. Нигүүлслийн эрин үе Есүсийн нэрээр эхэлсэн юм. Есүсийг үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэхэд Ариун Сүнс Есүсийн нэрийг гэрчилж эхэлсэн бөгөөд Еховагийн нэрийг хэлэхээ больсон; харин үүний оронд Ариун Сүнс үндсэндээ Есүсийн нэрийн дор шинэ ажил хийжээ. Түүнд итгэж байсан хүмүүсийн гэрчлэл Есүс Христийн төлөө хийгдсэн ба тэдний хийсэн ажил ч бас Есүс Христийн төлөө байлаа. Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийн төгсгөл нь үндсэндээ Еховагийн нэрийн дор явагдсан ажил дууссан гэсэн утгатай байв. Үүнээс хойш Бурханы нэр Ехова байхаа больсон; оронд нь Тэр Есүс гэж нэрлэгдсэн бөгөөд энэ үеэс эхлээд Ариун Сүнс үндсэндээ Есүсийн нэрийн дор ажил эхлүүлжээ. Иймээс өнөөдөр Еховагийн үгийг идэж, уусаар байгаа, мөн Хуулийн эрин үеийн ажлын дагуу бүхнийг хийсээр байгаа хүн—чи дүрэм журмыг сохроор мөрдөж

байгаа бус уу? Чи өнгөрсөн үед гацчихаагүй гэж үү? Эцсийн өдрүүд ирсэн гэдгийг чи одоо мэднэ. Есүс ирэх үедээ Есүс гэж нэрлэгдсээр л байх юм гэж үү? Ехова Израилийн ард түмэнд Мессиа ирнэ гэж хэлсэн ч ирэх үедээ Тэрээр Мессиа биш, харин Есүс гэж нэрлэгдэж байв. Өөрөө дахин ирнэ, явсан шигээ ирнэ гэж Есүс хэлсэн. Эдгээр нь Есүсийн үг байсан боловч Есүс ямар байдлаар явсныг чи харсан уу? Есүс цагаан үүл хөлөглөн явж одсон, гэхдээ Тэр цагаан үүл хөлөглөн хүмүүсийн дунд биечлэн ирэх юм гэж үү? Хэрвээ тэгсэн бол Түүнийг Есүс гэж нэрлэсээр байх бус уу? Есүсийг дахин ирэх үед эрин үе аль хэдийн өөрчлөгдсөн байх тул Түүнийг Есүс гэж нэрлэсээр байж болох уу? Бурханыг зөвхөн Есүсийн нэрээр л мэдэж болох юм гэж үү? Түүнийг шинэ эрин үед шинэ нэрээр нэрлэж болохгүй гэж үү? Нэг хүний дүр төрх болон тодорхой нэг нэр Бурханыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Эрин үе бүрд Бурхан шинэ ажил хийж, шинэ нэрээр нэрлэгддэг; Тэр яаж өөр өөр эрин үед адилхан ажил хийж чадах юм бэ? Тэр яаж хуучинтай зууралдаж чадах юм бэ? Есүсийн нэрийг золин авралын төлөө авсан, иймээс эцсийн өдрүүдэд эргэж ирэх үедээ Тэр адилхан нэрээр нэрлэгдсээр байх уу? Тэр золин авралын ажлыг хийсээр байх уу? Ехова, Есүс хоёр нэг атлаа яагаад өөр өөр эрин үед өөр нэрээр нэрлэгддэг юм бэ? Тэдний ажлын эрин үе ялгаатайгаас болдоггүй гэж үү? Ганц нэр Бурханыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Тийм болохоор Бурхан өөр өөр эрин үед өөр нэрээр нэрлэгдэх ёстой бөгөөд эрин үеийг өөрчилж, эрин үеийг төлөөлөхийн тулд нэр ашиглах ёстой. Учир нь нэг ч нэр Бурханыг Өөрийг нь бүрэн төлөөлж чадахгүй бөгөөд нэр болгон тухайн эрин үе дэх цаг хугацааны талын Бурханы зан чанарыг л төлөөлж чаддаг; энэ нь Түүний ажлыг төлөөлдөг байхад л хангалттай. Тиймээс бүхий л эрин үеийг төлөөлөхийн тулд Бурхан Өөрийн зан чанарт тохирох ямар ч нэрийг сонгож болно. Еховагийн эрин үе, эсвэл Есүсийн эрин үе байх нь хамаагүй, эрин үе бүрийг нэр төлөөлдөг. Нигүүлслийн эрин үеийн төгсгөлд эцсийн эрин үе хүрэлцэн ирсэн бөгөөд Есүс аль хэдийн ирчихсэн. Түүнийг яаж Есүс гэж нэрлэсээр байж болох юм бэ? Тэр яаж хүмүүсийн дунд Есүсийн дүртэй хэвээр байж болох юм бэ? Есүс Назарын дүр төрхтэйгөөс цаашгүй байсныг чи мартчихав уу? Есүс хүн төрөлхтний Золин аврагч л байсныг чи мартчихсан уу? Эцсийн өдрүүдэд хүнийг байлдан дагуулж, төгс болгох ажлыг Тэр яаж хариуцаж чадах юм бэ? Есүс цагаан үүл хөлөглөн явсан—энэ бол баримт—гэхдээ Тэр яаж хүмүүсийн дунд цагаан үүлэн дээр эргэн ирж, Есүс гэж нэрлэгдсээр байж болох юм бэ? Хэрвээ Тэр үнэхээр үүлэн дээр ирсэн бол хүн яаж Түүнийг танихгүй байх юм бэ? Дэлхий дахины хүмүүс Түүнийг танихгүй гэж үү? Тэр тохиолдолд, Есүс ганцаараа Бурхан байх бус уу? Тэр тохиолдолд Бурханы дүр нь Иудей хүний төрх байх байсан бөгөөд түүнчлэн үүрд өөрчлөгдөхгүй байх байлаа. Явсан шигээ ирэх болно гэж Есүс хэлсэн боловч Түүний үгийн жинхэнэ утгыг чи мэдэх үү? Тэр энэ бүлэг хүмүүс та нарт хэлсэн юм гэж үү? Тэрээр үүл хөлөглөн явсан шигээ ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Бурхан Өөрөө ажлаа яг яаж хийдгийг мэдэх үү? Хэрвээ чи үнэхээр харж чаддаг байсан бол Есүсийн хэлсэн үгийг хэрхэн тайлбарлах вэ? Тэрээр: Эцсийн

өдрүүдэд хүний Хүүг ирэхэд Тэр Өөрөө мэдэхгүй, тэнгэрэлчүүд мэдэхгүй, тэнгэр дэх элчүүд мэдэхгүй, бүх хүн мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ, өөрөөр хэлбэл, Сүнс л мэднэ гэж хэлсэн юм. Хүний Хүү Өөрөө ч мэдэхгүй атал чи харж, мэдэж чадна гэж үү? Хэрвээ чи мэдэх, нүдээрээ харах чадвартай байсан бол эдгээр үгийг хий дэмий хэлсэн юм биш үү? Тухайн үед Есүс юу гэж хэлсэн бэ? “Харин тэр өдөр цагийг хэн ч мэдэхгүй, тэнгэрийн тэнгэрэлчүүд ч мэдэхгүй, Хүү ч мэдэхгүй, зөвхөн Миний Эцэг л мэднэ. Гэхдээ хүний Хүүгийн ирэлт нь ч бас Ноагийн өдрүүд шиг байх болно… Тиймээс та нар бас бэлэн бай. Хүний Хүү та нарын бодоогүй цаг мөчид ирнэ.” Тэр өдөр ирэхэд хүний Хүү Өөрөө ч мэдэхгүй. Хүний Хүү гэдэг нь Бурханы махбод болсон биеийг, хэвийн агаад эгэл жирийн хүнийг хэлдэг. Хүний Хүү Өөрөө ч мэддэггүй, тэгвэл чи яаж мэдэж чадах юм бэ? Явсан шигээ ирнэ гэж Есүс хэлсэн. Ирэх үедээ Тэр Өөрөө ч мэдэхгүй, тэгвэл Тэр чамд урьдчилан мэдэгдэж чадах уу? Чи Түүний ирэхийг харж чадах уу? Тэр нь инээдтэй хэрэг биш үү? Бурхан газар дээр ирэх бүрдээ Өөрийн нэр, хүйс, дүр төрх болон ажлыг өөрчилдөг; Тэр Өөрийн ажлыг давтдаггүй. Тэр бол үргэлж шинэ агаад хэзээ ч хуучин байдаггүй Бурхан билээ. Өмнө нь ирэх үедээ Тэр Есүс гэж нэрлэгддэг байв; энэ удаа дахин ирэх үедээ Тэр Есүс гэж нэрлэгдсээр байж болох уу? Өмнө нь ирэх үедээ Тэр эрэгтэй байсан; энэ удаа Тэр дахиад эрэгтэй байж болох уу? Нигүүлслийн эрин үед ирэхдээ Түүний ажил нь загалмайд цовдлогдох явдал байсан; дахин ирэх үедээ Тэр мөн л хүн төрөлхтнийг нүглээс золин аварч болох уу? Тэр дахин загалмайд цовдлогдож болох уу? Тэгэх нь Өөрийн ажлыг давтаж байгаа хэрэг болох бус уу? Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүйг чи мэдэхгүй гэж үү? Бурхан хувиршгүй гэж хэлдэг хүмүүс бий. Тэр зөв, гэхдээ энэ нь Бурханы зан чанар болон мөн чанарын хувиршгүй байдлыг хэлдэг. Түүний нэр болон ажилд гарсан өөрчлөлт нь Түүний мөн чанар өөрчлөгдсөн гэдгийг нотолдоггүй; өөрөөр хэлбэл, Бурхан үргэлж Бурхан байх бөгөөд энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэрвээ чи, Бурханы ажил өөрчлөгдөшгүй гэж хэлбэл зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө Тэр дуусгаж чадах байсан уу? Бурхан үүрд өөрчлөгдөшгүй гэдгийг л чи мэднэ, гэхдээ Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин биш гэдгийг чи мэдэх үү? Хэрвээ Бурханы ажил өөрчлөгдөшгүй юм бол Тэр хүн төрөлхтнийг өнөөг хүртэл удирдаж чадах байсан гэж үү? Хэрвээ Бурхан хувиршгүй юм бол Тэр яагаад хоёр эрин үеийн ажлыг аль хэдийн хийчихсэн юм бэ? Түүний ажил урагшлахаа хэзээ ч больдоггүй, өөрөөр хэлбэл, Түүний зан чанар хүнд аажмаар илчлэгддэг бөгөөд илчлэгддэг зүйл нь Түүний төрөлх зан чанар юм. Анх Бурханы зан чанар хүнээс нуугдмал байсан, Тэр Өөрийн зан чанарыг хүнд хэзээ ч ил тод илчилж байгаагүй бөгөөд хүн Түүний талаар огт мэддэггүй байсан. Үүнээс болоод Тэр зан чанараа хүнд аажмаар илчлэхийн тулд Өөрийн ажлыг ашигладаг боловч ийм маягаар ажиллах нь Бурханы зан чанар эрин үе бүрд өөрчлөгддөг гэсэн үг биш юм. Бурханы хүсэл үргэлж өөрчлөгдөж байгаа учраас зан чанар нь байнга өөрчлөгдөж байдаг юм биш. Харин ч Түүний ажлын эрин үеүд өөр өөр байдгаас болоод Бурхан, хүн Өөрийг нь

мэддэг болж чадах байх гэсэндээ Өөрийн төрөлх зан чанарыг бүхэлд нь аваад, хүнд алхам алхмаар илчилдэг. Гэхдээ энэ нь, Бурхан анх ямар ч тодорхой зан чанаргүй байсан, эсвэл эрин үе өөрчлөгдөхийн хэрээр Түүний зан чанар аажмаар өөрчлөгдсөн гэдгийн нотолгоо яавч биш—ийм ойлголт нь андуу ташаа юм. Өөр өөр эрин үеийн дагуу Бурхан Өөрийн төрөлхийн болон тодорхой зан чанарыг—Тэр юу болохоо хүнд илчилдэг; ганц эрин үеийн ажил Бурханы бүх зан чанарыг илэрхийлж чадахгүй. Иймээс “Бурхан үргэлж шинэ агаад хэзээ ч хуучин биш” хэмээх үг нь Түүний ажлыг хэлдэг бөгөөд “Бурхан хувиршгүй” хэмээх үг нь Бурханд төрөлхөөсөө юу байгаа, Тэр юу болохыг хэлдэг. Ямартай ч чи зургаан мянган жилийн ажлыг ганц зүйлд хамааруулж болохгүй, эсвэл үхмэл үгээр хязгаарлаж болохгүй. Энэ нь хүний тэнэглэл юм. Бурхан хүний төсөөлдөг шиг энгийн биш бөгөөд Түүний ажил аль нэг эрин үед саатаж болохгүй. Жишээ нь, Ехова гэдэг нэр үүрд Бурханы нэр байж болохгүй; Бурхан Өөрийн ажлыг Есүсийн нэрээр ч бас хийж чадна. Энэ бол Бурханы ажил үргэлж урагш ахиж байдгийн тэмдэг билээ.

Бурхан бол үргэлж Бурхан бөгөөд хэзээ ч Сатан болохгүй; Сатан бол үргэлж Сатан ба хэзээ ч Бурхан болохгүй. Бурханы мэргэн ухаан, Бурханы гайхалтай байдал, Бурханы зөвт байдал, Бурханы сүр жавхлан хэзээ ч өөрчлөгдөхгүй. Түүний мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болох нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Харин Түүний ажлын тухайд бол, энэ нь үргэлж урагшилж, үргэлж гүнзгийрч байдаг, учир нь Тэр бол үргэлж шинэ, хэзээ ч хуучин биш билээ. Эрин үе болгонд Бурхан шинэ нэр авдаг, эрин үе бүрд Тэр шинэ ажил хийдэг, эрин үе бүрд Тэрээр бүтээлүүддээ Өөрийн шинэ хүсэл, шинэ зан чанарыг харуулдаг. Хэрвээ шинэ эрин үед хүмүүс Бурханы шинэ зан чанарын илэрхийллийг харж чадахгүй бол Түүнийг загалмайд үүрд цовдлохгүй гэж үү? Ингэснээрээ тэд Бурханыг хязгаарлахгүй гэж үү? Хэрвээ Бурхан зөвхөн эрэгтэй болж махбодод ирсэн бол хүмүүс Түүнийг эрэгтэй гэж, эрэгтэй хүмүүсийн Бурхан гэж хязгаарлах байсан бөгөөд Тэр бол эмэгтэйчүүдийн Бурхан гэдэгт хэзээ ч итгэхгүй байх байв. Эрэгтэйчүүд тэгээд, Бурхан бол эрэгтэй хүмүүстэй адилхан хүйстэй, Бурхан бол эрэгтэйчүүдийн тэргүүн гэж үзэх байлаа—тэгвэл эмэгтэйчүүд яах вэ? Энэ бол шударга бус; энэ нь ялгаварласан хандлага биш гэж үү? Хэрвээ тийм байсан бол Бурханы аварсан хүмүүс бүгд Түүнтэй адил эрэгтэй байх байсан бөгөөд ганц ч эмэгтэй хүн аврагдахгүй байх байсан юм. Бурхан хүн төрөлхтнийг бүтээхдээ Адамыг бүтээсэн, мөн Еваг бүтээсэн. Тэрээр Адамыг бүтээснээр үл барам, эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь Өөрийнхөө дүрээр бүтээсэн юм. Бурхан зөвхөн эрэгтэйчүүдийн Бурхан биш—Тэр бас эмэгтэйчүүдийн Бурхан. Бурхан эцсийн өдрүүд дэх ажлын шинэ үе шатанд орсон. Тэрээр Өөрийн зан чанарыг улам их илчлэх бөгөөд энэ нь Есүсийн цаг үеийн энэрэл, хайр биш байх болно. Түүнд шинэ ажил байгаа тул энэ шинэ ажлыг шинэ зан чанар дагалдана. Иймээс хэрвээ энэ ажлыг Сүнс хийсэн бол—хэрвээ Бурхан махбод болоогүй, харин оронд нь Сүнс аянгын дуугаар дамжуулан шууд ярьж, хүн Түүнтэй харилцах ямар ч аргагүй байсан бол хүн Түүний зан чанарыг мэдэж чадах байсан

уу? Хэрвээ ажлыг гагцхүү Сүнс хийсэн бол хүн Бурханы зан чанарыг мэдэж авах ямар ч аргагүй байх байлаа. Бурханыг махбод болох үед, Үг махбодоор илрэх үед л хүмүүс Бурханы зан чанарыг нүдээрээ харж чадах бөгөөд Тэр Өөрийн бүх зан чанарыг махбодоор илэрхийлдэг. Бурхан үнэхээр, жинхэнээсээ хүмүүсийн дунд амьдардаг. Тэр бол биет; хүн Түүний зан чанартай бодитоор харилцаж, Түүнд юу байгаа, Тэр юу болохтой харилцаж чадна; зөвхөн ийм маягаар л хүн Түүнийг үнэхээр мэдэж авч чадна. Үүний зэрэгцээ Бурхан бас “Бурхан бол эрэгтэйчүүдийн Бурхан, мөн эмэгтэйчүүдийн Бурхан” гэх ажлыг гүйцэлдүүлж, махбод дахь ажлаа бүхэлд нь гүйцэтгэсэн юм. Тэр ямар ч эрин үед ажлыг давхардуулдаггүй. Эцсийн өдрүүд ирчихсэн тул Тэр эцсийн өдрүүдэд хийдэг ажлаа хийх бөгөөд эцсийн өдрүүд дэх бүхий л зан чанараа илчилдэг. Эцсийн өдрүүдийн тухай ярих юм бол, энэ нь тусдаа эрин үеийг хэлдэг, Есүсийн хэлснээр энэ эрин үед та нарт гарцаагүй гамшиг тулгарч, газар хөдлөлт, өлсгөлөн, тахал тулгарах бөгөөд хуучны Нигүүлслийн эрин үе байхаа болиод, шинэ эрин үе иржээ гэдгийг энэ нь харуулна. Хүмүүсийн хэлдгээр Бурхан үүрд өөрчлөгдөшгүй, зан чанар нь үргэлж өршөөнгүй агаад хайр энэрэлтэй, хүнийг Өөр шигээ хайрладаг, хүн бүрд аврал өгч, хүнийг хэзээ ч үзэн яддаггүй байсан бол Түүний ажил ер нь дуусаж чадах байсан уу? Есүс ирж, загалмайд цовдлогдон, бүх нүгэлтний төлөө Өөрийгөө золиосолж, тахилын ширээн дээр Өөрийгөө өргөл болгохдоо золин авралын ажлыг аль хэдийн гүйцэлдүүлж, Нигүүлслийн эрин үеийг төгсгөсөн юм. Тэгвэл тэр эрин үеийн ажлыг эцсийн өдрүүдэд давтах нь ямар хэрэгтэй юм бэ? Нэг зүйлээ хийх нь Есүсийн ажлыг үгүйсгэсэн хэрэг бус уу? Хэрвээ Бурхан энэ үе шатанд ирэхдээ цовдлолын ажил хийгээгүй боловч хайр энэрэлтэй, өршөөнгүй хэвээр үлдсэн бол эрин үеийг төгсгөж чадах байсан уу? Хайр энэрэлтэй, өршөөнгүй Бурхан эрин үеийг төгсгөж чадах байсан уу? Эрин үеийг төгсгөх эцсийн ажилд Бурханы зан чанар нь гэсгээлт, шүүлтийн зан чанар байдаг бөгөөд Тэрээр бүх хүнийг ил тод шүүж, Өөрийг нь чин сэтгэлээсээ хайрладаг хүмүүсийг төгс болгохын тулд зөв шударга бус бүхнийг илчилдэг. Зөвхөн ийм зан чанар л эрин үеийг төгсгөж чадна. Эцсийн өдрүүд аль хэдийн ирчихсэн. Бүтээлийн бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдаж, шинж чанарынхаа үндсэн дээр өөр өөр төрөлд хуваагдана. Энэ бол Бурхан хүмүүсийн төгсгөлийг, мөн хүрэх газрыг илчилдэг мөч юм. Хэрвээ хүмүүс гэсгээлт, шүүлт туулахгүй бол дуулгаваргүй байдал болон зөв шударга бус байдлыг нь ил болгох ямар ч аргагүй байх болно. Гэсгээлт, шүүлтээр л бүх бүтээлийн төгсгөлийг илчилж болно. Гэсгээгдэж, шүүгдэх үедээ л хүн жинхэнэ төрхөө харуулдаг. Мууг нь муутай, сайныг нь сайнтай тавих бөгөөд бүх хүн төрлийнхөө дагуу ангилагдана. Гэсгээлт, шүүлтээр дамжуулан бүх бүтээлийн төгсгөл илчлэгдэнэ, ингэснээр муу нь шийтгүүлж, сайн нь шагнуулж, бүх хүн Бурханы эрх мэдэлд харьяалагдаж болох юм. Энэ бүх ажил зөв шударга гэсгээлт, шүүлтээр хийгдэх ёстой. Хүний завхрал дээд цэгтээ хүрч, дуулгаваргүй байдал нь хэтэрхий ноцтой болсон учраас үндсэндээ гэсгээлт, шүүлтээс бүрддэг, эцсийн өдрүүдэд илчлэгддэг Бурханы зөвт

зан чанар л хүнийг бүрмөсөн өөрчилж, бүрэн төгс болгож чадна. Энэ зан чанар л мууг ил болгож, улмаар зөв шударга бус бүхнийг хатуу шийтгэж чадна. Тиймээс ийм зан чанарт эрин үеийн ач холбогдол шингэсэн байдаг бөгөөд Түүний зан чанарын илчлэл болон илрэл нь шинэ эрин үе бүрийн ажлын төлөө илэрхийлэгддэг. Бурхан Өөрийн зан чанарыг дур зоргоороо, ач холбогдолгүйгээр илчилдэг юм биш. Эцсийн өдрүүдэд хүний төгсгөлийг илчлэхдээ Бурхан хүнд хязгааргүй өршөөл, хайр харуулж, түүнийг үргэлжлүүлэн хайрлаж, хүнд зөвт шүүлт хүртээхгүй, харин ч хүлээцтэй байдал, тэвчээр, уучлал үзүүлж, нүгэл нь хэчнээн ноцтой байсан ч өчүүхэн ч зөвт шүүлтгүйгээр хүнийг өршөөсөөр байсан бол Бурханы бүх удирдлага хэзээ ер нь дуусах юм бэ? Ийм зан чанар хэзээ хүмүүсийг хүн төрөлхтөнд тохирох хүрэх газар луу хөтөлж чадах юм бэ? Жишээлбэл, үргэлж бусдыг хайрладаг, эелдэг царай, зөөлөн зүрх сэтгэлээр шүүдэг шүүгчийг аваад үз. Тэрээр, үйлдсэн нүглээс нь үл хамааран хүмүүсийг хайрладаг ба хэн ч байлаа гэсэн, хайр энэрэлтэй, тэвчээртэй ханддаг. Тийм тохиолдолд тэр хэзээ ер нь шударга ялын тогтоол гаргаж чадах юм бэ? Эцсийн өдрүүдийн үеэр зөвт шүүлт л хүнийг төрлөөр нь ангилж, шинэ ертөнцөд аваачиж чадна. Ийм маягаар, Бурханы шүүлт, гэсгээлтийн зөвт зан чанараар дамжуулан бүхий л эрин үе төгсдөг.

Бурханы бүх удирдлага дахь ажил тов тодорхой байдаг: Нигүүлслийн эрин үе бол Нигүүлслийн эрин үе, эцсийн өдрүүд бол эцсийн өдрүүд юм. Эрин үе бүрийн хооронд тодорхой ялгаа байдаг, учир нь эрин үе бүрд Бурхан, тухайн эрин үеийг төлөөлөх ажлыг хийдэг. Эцсийн өдрүүдийн ажил хийгдэхийн тулд эрин үеийг төгсгөлд нь аваачих шатаалт, шүүлт, гэсгээлт, уур хилэн, сүйрэл байх ёстой. Эцсийн өдрүүд гэж сүүлчийн эрин үеийг хэлдэг. Сүүлчийн эрин үед Бурхан эрин үеийг төгсгөхгүй гэж үү? Эрин үеийг төгсгөхийн тулд Бурхан гэсгээлт, шүүлт авчрах ёстой. Ийм маягаар л Тэр эрин үеийг төгсгөж чадна. Есүсийн зорилго нь хүнийг үргэлжлүүлэн амьд үлдээж, амьдруулж, илүү дээр байдлаар оршин тогтнуулахын төлөө байсан юм. Тэрээр хүний доройтохыг болиулж, Үхэгсдийн орон болон тамд амьдрахыг нь болиулахын тулд нүглээс аварсан бөгөөд хүнийг Үхэгсдийн орон болон тамаас аварснаараа Есүс үргэлжлүүлэн амьдрах боломжийг хүнд олгосон билээ. Одоо эцсийн өдрүүд ирчихсэн. Бурхан хүнийг устгаж, хүн төрөлхтнийг бүрмөсөн сүйрүүлнэ, өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний тэрслүү байдлыг өөрчилнө. Энэ шалтгааны улмаас, урьдын өршөөнгүй, хайр энэрэлтэй зан чанараар Бурхан эрин үеийг төгсгөх юм уу зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө биелүүлэх боломжгүй байх байв. Эрин үе бүрд онцгой төлөөлөх зан чанар байдаг ба эрин үе бүр Бурханы хийх ёстой ажлыг агуулдаг. Иймээс, эрин үе бүрд Бурханы Өөрийн хийдэг ажил жинхэнэ зан чанарынх нь илэрхийллийг агуулдаг бөгөөд Түүний нэр болон Түүний хийдэг ажил хоёулаа эрин үеийн хамтаар өөрчлөгддөг—тэдгээр нь бүгд шинэ байдаг. Хуулийн эрин үед хүн төрөлхтнийг залж чиглүүлэх ажил Еховагийн нэрийн дор хийгдсэн бөгөөд ажлын эхний үе шат газар дээр хийгдсэн. Энэ үе шатны ажил нь сүм болон тахилын ширээ барих, мөн Израилийн

ард түмнийг залж чиглүүлж, тэдний дунд ажиллахын тулд хууль ашиглахаас бүрдэж байв. Израилийн ард түмнийг залж чиглүүлснээр Тэр газар дээрх Өөрийн ажлын суурийг тавьсан юм. Энэ суурин дээрээс Тэр Өөрийн ажлыг Израилиас цааш өргөжүүлсэн, өөрөөр хэлбэл, Израилиас эхлээд Өөрийн ажлыг гадагш тэлсэн, ингэснээр хожмын үеийнхэн, Ехова бол Бурхан бөгөөд тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн, мөн Ехова бүх бүтээлийг бүтээсэн гэдгийг мэдэж авсан билээ. Израилийн ард түмнээр дамжуулан Тэрээр Өөрийн ажлыг тэднээс цааш түгээсэн юм. Израилийн газар нутаг Еховагийн газар дээрх ажлын анхны ариун газар байсан бөгөөд Израилийн газар нутагт Бурхан анх ажиллахаар очжээ. Тэр нь Хуулийн эрин үеийн ажил байв. Нигүүлслийн эрин үед Есүс хүнийг аварсан Бурхан байлаа. Түүнд юу байсан, Тэр юу болох нь нигүүлсэл, хайр, энэрэл, өршөөл, тэвчээр, даруу төлөв байдал, халамж, хүлээцтэй байдал байсан бөгөөд Түүний хийсэн ажлын дийлэнх нь хүнийг золин аврахын төлөө байв. Түүний зан чанар энэрэл, хайрын зан чанар байсан ба Тэр энэрэнгүй, элэгсэг байсан учраас тэдний төлөө Өөрийгөө бүхэлд нь өргөл болгож чадах хэмжээнд Бурхан хүнийг Өөр шигээ хайрладаг гэдгийг харуулахын тулд хүний төлөө загалмайд цовдлогдох ёстой болсон юм. Нигүүлслийн эрин үед Бурханы нэр Есүс байсан, өөрөөр хэлбэл, Бурхан бол хүнийг аварсан Бурхан байсан бөгөөд энэрэнгүй, элэгсэг Бурхан байв. Бурхан хүнтэй хамт байлаа. Түүний хайр, Түүний энэрэл, Түүний аврал хүн нэг бүрийг дагалджээ. Есүсийн нэрийг болон Түүнийг байгааг хүлээн авснаар л хүн амар амгалан, баяр хөөрийг олж авч, Түүний ерөөл, асар их, хэмжээлшгүй нигүүлсэл, авралыг хүртэж чадсан юм. Есүсийн цовдлолоор дамжуулан Түүнийг дагаж байсан бүх хүн аврал хүртэж, нүглээ уучлуулжээ. Нигүүлслийн эрин үед Есүс гэдэг нь Бурханы нэр байлаа. Өөрөөр хэлбэл, Нигүүлслийн эрин үеийн ажил үндсэндээ Есүсийн нэрийн дор хийгдсэн юм. Нигүүлслийн эрин үед Бурханыг Есүс гэж нэрлэж байв. Тэрээр Хуучин Гэрээнээс даван гарсан шинэ ажлын үе шатыг хийсэн бөгөөд цовдлолын хамтаар Түүний ажил дуусчээ. Энэ нь бүхэлдээ Түүний ажил байв. Тиймээс Хуулийн эрин үед Ехова гэдэг нь Бурханы нэр байсан ба Нигүүлслийн эрин үед Есүсийн нэр Бурханыг төлөөлсөн юм. Эцсийн өдрүүдэд Түүний нэр бол Төгс Хүчит Бурхан—хүнийг залж чиглүүлж, байлдан дагуулж, олж авч, эцэст нь эрин үеийг төгсгөхийн тулд Өөрийн хүч чадлыг ашигладаг Төгс Хүчит билээ. Эрин үе бүрд, Түүний ажлын үе шат болгонд Бурханы зан чанар илэрхий байдаг.

Анх Хуучин Гэрээний Хуулийн эрин үед хүнийг залж чиглүүлэх нь хүүхдийн амьдралыг залж чиглүүлэхтэй адилхан байлаа. Анхны хүн төрөлхтөн Еховагаас дөнгөж төрсөн байв; тэд бол израильчууд байсан юм. Тэдэнд Бурханыг хэрхэн хүндлэх тухай, эсвэл газар дээр хэрхэн амьдрах талаар ямар ч ойлголт байсангүй. Өөрөөр хэлбэл, Ехова хүн төрөлхтнийг буюу Адам, Еваг бүтээсэн боловч тэдэнд Еховаг хэрхэн хүндэлж, газар дээр Еховагийн хуулийг хэрхэн дагах талаар ойлгох эрхтэн өгөөгүй байсан юм. Еховагийн шууд удирдамжгүйгээр хэн ч үүнийг шууд мэдэж чадаагүй, учир нь анх хүнд тийм эрхтэн байхгүй байв. Ехова бол Бурхан

гэдгийг л хүн мэдэж байсан, харин Түүнийг хэрхэн хүндлэх, яаж биеэ авч явбал Түүнийг хүндэлж байгаад тооцогдох, ямар сэтгэлээр Түүнийг хүндлэх ёстой, эсвэл Түүнийг хүндлэхдээ юуг тахил болгох ёстойг хүн огт мэддэггүй байлаа. Еховагийн бүтээсэн бүх зүйлийн дундаас эдэлж болох зүйлийг хэрхэн эдлэхээ л хүн мэддэг байсан, харин газар дээр чухам яаж амьдрах нь Бурханы бүтээл гэх нэрд зохих талаар огт мэддэггүй байв. Тэдэнд зааварлах хэн ч байхгүй бол, тэднийг биечлэн залж чиглүүлэх хэн ч байхгүй бол энэ хүн төрөлхтөн, хүмүүст зүй ёсоор тохирох амьдралаар хэзээ ч амьдрахгүй, харин үл анзаарагдам байдлаар Сатанд олзлогдсоор байх байсан юм. Ехова хүн төрөлхтнийг бүтээсэн, өөрөөр хэлбэл, Тэрээр хүн төрөлхтний өвөг дээдэс болох Адам, Еваг бүтээсэн боловч тэдэнд илүү их оюун ухаан, эсвэл мэргэн ухаан хайрлаагүй юм. Хэдий тэд аль хэдийн газар дээр амьдарч байсан ч бараг юу ч ойлгоогүй юм. Иймээс хүн төрөлхтнийг бүтээх Еховагийн ажлын хагас нь л дууссан бөгөөд бүрэн гүйцэлдээгүй байв. Тэрээр зөвхөн шорооноос хүний загварыг бүтээгээд Өөрийн амьсгалыг өгсөн боловч Өөрийг нь хүндлэх хангалттай хүсэл зоригийг хүнд хайрлаагүй юм. Анх хүнд Түүнийг хүндлэх, эсвэл Түүнээс эмээх оюун санаа байгаагүй. Хүн Түүний үгийг хэрхэн сонсохоо л мэддэг байсан боловч газар дээрх амьдрал болон хүний амьдралын хэвийн дүрэм журмын талаарх үндсэн мэдлэгийг мэддэггүй байлаа. Иймээс хэдийгээр Ехова эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээж, долоон өдрийн туурвилаа дуусгасан боловч хүнийг бүтээх үйлээ яавч бүрэн төгс болгоогүй, учир нь хүн гадаад бүрхүүл төдий байсан ба хүн байх бодит байдалгүй байлаа. Хүн төрөлхтнийг Ехова бүтээсэн гэдгийг л хүн мэддэг байсан боловч Еховагийн үгийг юм уу хуулийг хэрхэн мөрдөх талаар өчүүхэн ч мэддэггүй байв. Иймээс хүн төрөлхтөн бий болсны дараа Еховагийн ажил огтхон ч дуусах болоогүй байсан юм. Тэрээр хүн төрөлхтнийг Өөрийнхөө өмнө ирүүлэхийн тулд мөн л бүрэн залж чиглүүлэх хэрэгтэй байлаа, ингэснээр тэд газар дээр хамт амьдарч, Түүнийг хүндэлж чаддаг болж магад байсан ба Түүний удирдамжтайгаар газар дээрх хэвийн хүний амьдралын зөв замд орж магад байв. Ийм маягаар л үндсэндээ Еховагийн нэрийн дор явагдсан ажил бүрэн дууссан; өөрөөр хэлбэл, зөвхөн ийм маягаар л дэлхийг бүтээх Еховагийн ажил бүрэн дууссан юм. Иймээс, хүн төрөлхтнийг бүтээгээд Тэр хэдэн мянган жилийн турш газар дээрх хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэх хэрэгтэй болсон ба ийнхүү хүн төрөлхтөн Түүний зарлиг болон хуулийг мөрдөж, газар дээрх хэвийн хүний амьдралын бүх үйл ажиллагаанд оролцож чадах байсан юм. Тэр үед л Еховагийн ажил бүрэн дууссан. Хүн төрөлхтнийг бүтээсний дараа Тэр энэ ажлыг хийж, Иаковын эрин хүртэл үүнийг үргэлжлүүлсэн ба тухайн үед Тэрээр Иаковын арван хоёр хүүг Израилийн арван хоёр овог болгосон билээ. Тэр цагаас эхлээд Израилийн бүх ард түмэн газар дээр Түүгээр албан ёсоор удирдуулсан хүмүүс болж, Израиль нь газар дээрх Түүний ажлын тусгай байршил болсон билээ. Ехова энэ хүмүүсийг, газар дээрх ажлаа албан ёсоор хийх эхний бүлэг хүмүүс болгосон бөгөөд Израилийн бүх газар нутгийг

Өөрийн ажлын эхлэлийн цэг болгож, тэднийг бүр ч илүү агуу ажлын эхлэл болгон ашигласан, ингэснээр газар дээр Түүнээс төрсөн бүх хүн Түүнийг хэрхэн хүндэлж, газар дээр хэрхэн амьдрахаа мэдэх байсан юм. Иймээс израильчуудын үйл хэрэг нь Харь үндэстний хүмүүсийн дагах үлгэр жишээ болсон бөгөөд Израилийн ард түмний дунд хэлсэн зүйл нь Харь үндэстний хүмүүсийн сонсох үг болжээ. Учир нь тэд Еховагийн хууль болон тушаалыг эхлээд хүлээн авах хүмүүс байсан ба иймээс ч тэд бас Еховагийн замыг хэрхэн хүндлэхээ эхлээд мэдэж авах хүмүүс байсан юм. Тэд бол Еховагийн замыг мэддэг хүн төрөлхтний өвөг дээдэс, түүнчлэн Еховагийн сонгосон хүн төрөлхтний төлөөлөл байлаа. Нигүүлслийн эрин үе ирэхэд Ехова хүнийг ийм маягаар залж чиглүүлэхээ больсон. Хүн нүгэл үйлдэж, нүгэлд автсан тул Тэрээр хүнийг нүглээс аварч эхэлсэн юм. Ийм маягаар Тэр, нүглээс бүрэн гэтэлгэх хүртлээ хүнийг зэмлэжээ. Эцсийн өдрүүдэд хүн ийм түвшинд хүртлээ доройтсон учраас энэ үе шатны ажлыг зөвхөн шүүлт, гэсгээлтээр л дамжин явуулж болно. Ийм маягаар л ажлыг гүйцэлдүүлж болно. Энэ нь хэд хэдэн эрин үеийн ажил байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, нэг эрин үеийг нөгөөгөөс зааглаж, тэдгээрийн хооронд шилжилт хийхдээ Бурхан Өөрийн нэр, Өөрийн ажил болон өөр өөр Бурханы дүрийг ашигладаг; Бурханы нэр болон ажил нь Түүний эрин үеийг төлөөлж, эрин үе бүр дэх Түүний ажлыг төлөөлдөг. Эрин үе бүр дэх Бурханы ажил үргэлж адилхан байж, Түүнийг үргэлж нэг нэрээр нэрлэдэг байсан бол хүн Түүнийг яаж мэдэх юм бэ? Бурханыг Ехова гэж нэрлэх ёстой, Бурханыг Ехова гэж нэрлэхээс бусдаар, өөр ямар нэг нэрээр нэрлэгддэг нэгэн бол Бурхан биш. Аль эсвэл Бурхан зөвхөн Есүс байж болох ба Есүсийн нэрээс өөр ямар ч нэрээр Түүнийг нэрлэж болохгүй; Есүсээс бусад тохиолдолд, Ехова бол Бурхан биш, Төгс Хүчит Бурхан ч бас Бурхан биш. Бурхан төгс хүчит гэдэг нь үнэн боловч Бурхан бол хүнтэй хамт байдаг Бурхан, Түүнийг Есүс гэж нэрлэх ёстой, учир нь Бурхан хүнтэй хамт байдаг гэж хүн итгэдэг. Ингэх нь хоосон сургаал мөрдөж, Бурханыг тодорхой цар хүрээнд хязгаарлаж байгаа хэрэг юм. Иймээс эрин үе бүрд Бурханы хийдэг ажил, Түүнийг нэрлэдэг нэр, Түүний авдаг дүр төрх—өнөөдрийг хүртэлх үе шат болгонд Түүний хийдэг ажил—эдгээр нь ганц ч дэг журмыг дагадаггүй ба ямар ч хязгаарлалтад баригддаггүй. Тэр бол Ехова, гэхдээ Тэр бас Есүс, түүнчлэн Мессиа, Төгс Хүчит Бурхан юм. Түүний ажил алгуур өөрчлөлт туулж, Түүний нэрэнд зохих өөрчлөлт гардаг. Ганц ч нэр Түүнийг бүрэн төлөөлж чадахгүй, гэхдээ Түүнийг нэрлэдэг бүх нэр Түүнийг төлөөлж чаддаг бөгөөд эрин үе бүрд Түүний хийдэг ажил зан чанарыг нь төлөөлдөг. Эцсийн өдрүүд ирэх үед чиний хардаг Бурхан Есүс хэвээр байхаас гадна цагаан үүл хөлөглөн ирж, Есүсийн гадаад төрхтэй хэвээр байж, хэлдэг үг нь “Та нар хөршөө өөр шигээ хайрлах ёстой, мацаг барьж, залбирч, өөрийн амийг нандигнадаг шигээ дайснаа хайрлаж, бусдад хүлээцтэй хандаж, тэвчээртэй, даруу байх ёстой. Та нар Миний шавь болохоосоо өмнө энэ бүх зүйлийг хийх ёстой. Энэ бүх зүйлийг хийснээр Миний хаанчлалд орж болох юм” хэмээх Есүсийн үг байлаа гэж үзье. Энэ нь Нигүүлслийн эрин үеийн ажилд харьяалагдах бус уу? Түүний

хэлдэг зүйл Нигүүлслийн эрин үеийн зам байх бус уу? Хэрвээ эдгээр үгийг сонссон бол та нарт ямар санагдах байсан бэ? Энэ нь мөн л Есүсийн ажил гэж санагдахгүй гэж үү? Энэ нь ажлыг давтаж байгаа хэрэг биш үү? Хүн үүнээс таашаал авч чадах уу? Бурханы ажил энэ хэвээрээ л үлдээд, цааш ахиц гарахгүй. Түүнд ийм л хүч чадал байдаг ба хийх ямар ч шинэ ажил байхгүй, Түүний хүч чадал хязгаартаа хүрчихсэн гэж та нарт санагдах байсан. Одоогоос хоёр мянган жилийн өмнө Нигүүлслийн эрин үе байсан ба хоёр мянган жилийн дараа ч Тэр бас л Нигүүлслийн эрин үеийн замыг номлосоор, хүмүүсийг гэмшүүлсээр байвал хүмүүс: “Бурхан минь, Танд ердөө ийм л хүч чадал байдаг. Та маш ухаалаг гэж би бодож байна, гэхдээ Та зөвхөн хүлээцтэй байдлыг л мэддэг ба тэвчээрийг л анхаардаг, Та дайснаа хайрлахаас өөрийг мэддэггүй” гэх байлаа. Хүний оюун санаанд Бурхан үүрд Нигүүлслийн эрин үед байсантайгаа адил байх байсан бөгөөд Бурхан бол элэгсэг, энэрэнгүй гэж хүн үргэлж бодох байв. Бурханы ажил үргэлж хуучин замаараа алхана гэж чи бодож байна уу? Иймээс Өөрийнхөө ажлын энэ үе шатанд Тэр цовдлогдохгүй бөгөөд хардаг, хүрдэг бүхэн чинь та нарын төсөөлсөн юм уу сонссон юутай ч адилгүй байх болно. Өнөөдөр Бурхан фарисайчуудтай харилцдаггүй, мөн дэлхий ертөнцөд ч мэдэгддэггүй бөгөөд Түүнийг мэддэг хүмүүс бол Түүнийг дагадаг та нар л юм, учир нь Тэр дахин цовдлогдохгүй. Нигүүлслийн эрин үед Есүс сайн мэдээний ажлынхаа төлөө газар нутаг даяар ил тод номлосон. Цовдлолын ажлын төлөө Тэр фарисайчуудтай харилцсан; хэрвээ Тэр фарисайчуудтай харилцаагүй, эрх мэдэлтэй байсан хүмүүс Түүнийг огт мэддэггүй байсан бол яаж Тэр яллагдаж, дараа нь урвалт амсаж, загалмайд цовдлогдож чадах юм бэ? Иймээс Тэр цовдлолын төлөө фарисайчуудтай харилцсан юм. Өнөөдөр Тэр сорилтоос зайлсхийхийн тулд Өөрийн ажлыг нууцаар хийдэг. Бурхан хоёр удаа бие махбодтой болоход ажил болон ач холбогдол нь өөр, орчин нөхцөл нь ч өөр байдаг, тэгвэл Түүний хийдэг ажил яаж бүхэлдээ адилхан байж болох юм бэ?

“Бурхан бидэнтэй хамт” гэх Есүсийн нэр Бурханы зан чанарыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Бурханыг бүрэн илэрхийлж чадах уу? Бурханыг Есүс л гэж нэрлэж болно, Бурхан Өөрийн зан чанарыг өөрчилж болохгүй учраас өөр ямар ч нэртэй байж болохгүй гэж хүн хэлбэл энэ нь үнэхээр доромжлол юм! Бурхан бидэнтэй хамт хэмээх Есүс гэдэг нэр ганцаараа Бурханыг бүхэлд нь төлөөлж чадна гэж чи итгэж байна уу? Бурханыг олон нэрээр нэрлэж болно, гэхдээ энэ олон нэрийн дунд Бурханыг бүхэлд нь товчоор илэрхийлж чадах, Бурханыг бүрэн төлөөлж чадах ганц ч нэр байхгүй. Иймээс Бурханд олон нэр байдаг боловч энэ олон нэр нь Бурханы зан чанарыг бүрэн илэрхийлж чадахгүй, учир нь Бурханы зан чанар маш баялаг болохоор энэ нь Түүнийг мэдэх хүний чадвараас даван гардаг. Хүн төрөлхтний хэлийг ашиглан Бурханыг бүрэн илэрхийлэх ямар ч арга хүнд үгүй. Хүн төрөлхтний хувьд, Бурханы зан чанарын талаар мэддэг бүхнээ товчоор илэрхийлэх үгсийн сан хязгаарлагдмал байдаг: агуу, эрхэмсэг, гайхалтай, ойлгохын аргагүй, эрхэм дээд, ариун, зөвт, ухаалаг гэх мэт. Маш олон үг! Ийм

хязгаарлагдмал үгсийн сан нь Бурханы зан чанарын талаар хүний харсан өчүүхэн жаахан зүйлийг ч дүрслэх чадваргүй. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр өөр олон хүн, өөрсдийнх нь доторх оргилсон сэтгэлийг илүү сайн дүрсэлж чадна гэж бодсон үгийг нэмсэн: Бурхан маш агуу! Бурхан маш ариун! Бурхан маш хайр татам! Өнөөдөр хүний иймэрхүү үг хэллэг оргилдоо хүрсэн атал хүн өөрийгөө тодорхой илэрхийлэх чадваргүй хэвээр байгаа. Иймээс хүний хувьд, Бурхан олон нэртэй атлаа нэг ч нэргүй байдаг, учир нь Бурханы оршихуй маш элбэг арвин агаад хүний хэл тун хомсхон. Тодорхой нэг үг, эсвэл нэр Бурханыг бүхэлд нь төлөөлөх чадваргүй, тэгвэл Тэрээр тогтсон нэг нэртэй байж болно гэж чи бодож байна уу? Бурхан маш агуу, маш ариун атал шинэ эрин үе бүрд нэрээ өөрчлөхийг чи Түүнд зөвшөөрөхгүй юу? Тиймээс Өөрийн ажлыг биечлэн хийж байгаа эрин үе бүрдээ Бурхан, хийхээр зорьж буй ажлаа товчоор илэрхийлэхийн тулд тухайн эрин үед тохирох нэрийг ашигладаг. Тэрээр тухайн эрин үе дэх Өөрийн зан чанарыг төлөөлөхийн тулд цаг хугацааны ач холбогдол бүхий энэхүү тодорхой нэрийг ашигладаг. Энэ бол Өөрийн зан чанарыг илэрхийлэхийн тулд Бурхан хүн төрөлхтний хэлийг ашиглаж байгаа хэрэг юм. Тэгсэн ч гэсэн сүнслэг туршлагатай агаад Бурханыг биечлэн харсан олон хүнд, энэхүү тодорхой нэг нэр Бурханыг бүхэлд нь төлөөлөх чадваргүй гэж санагдсаар байдаг—аяа, үүнийг яах ч аргагүй—иймээс хүн Бурханыг ямар нэг нэрээр нэрлэхээ больж, Түүнийг зүгээр л “Бурхан” гэж дууддаг. Хүний зүрх сэтгэл хайраар дүүрэн мөртөө бас зөрчилдөөнд автсан мэт байдаг, учир нь хүн Бурханыг хэрхэн тайлбарлахаа мэддэггүй. Бурхан юу болох нь хэтэрхий элбэг дэлбэг тул үүнийг ердөө дүрслэх аргагүй. Бурханы зан чанарыг нэгтгэн дүгнэж чадах ганц ч нэр байхгүй бөгөөд Бурханд юу байгаа, Тэр юу болохыг дүрсэлж чадах ганц ч нэр байхгүй. Хэрвээ хүн Надаас, “Та яг ямар нэр ашигладаг вэ?” гэж асуувал Би түүнд “Бурхан бол Бурхан!” гэж хэлнэ. Тэр нь Бурханы хувьд хамгийн сайн нэр биш гэж үү? Бурханы зан чанарын хамгийн шилдэг товч илэрхийлэл биш гэж үү? Ийм байтал та нар яагаад Бурханы нэрийг эрж хайхад маш их хичээл чармайлт гаргадаг юм бэ? Ганц нэрийн төлөө яагаад тархиа гашилгаж, нойр, хоолоо умартана вэ? Бурханыг Ехова, Есүс, Мессиа гэж нэрлэхгүй өдөр ирнэ—Тэр зүгээр л Бүтээгч байх болно. Тэр үед, газар дээр Түүний авсан бүх нэр төгсгөл болно, учир нь газар дээрх Түүний ажил дуусчихсан байх бөгөөд үүний дараа Түүний нэрс байхаа болино. Бүх зүйл Бүтээгчийн эрх мэдэл дор очих үед туйлын зохистой атлаа бүрэн бус нэр Түүнд ямар хэрэгтэй байх юм бэ? Чи одоо ч Бурханы нэрийн араас хөөцөлдсөөр байна уу? Чи Бурханыг гагцхүү Ехова гэж нэрлэж болно гэж хэлж зүрхэлсээр байна уу? Бурханыг Есүс л гэж нэрлэж болно хэмээн хэлж зүрхэлсээр байна уу? Бурханыг доромжилсон нүглийг чи үүрч чадах уу? Бурхан анхнаасаа ямар ч нэргүй байсан гэдгийг чи мэдэж байх ёстой. Түүнд хийх ажил байсан ба хүн төрөлхтнийг удирдах хэрэгтэй болсон учраас л Тэр нэг, хоёр, эсвэл олон нэртэй болсон юм. Түүнийг ямар ч нэрээр нэрлэсэн бай—үүнийг Тэр Өөрөө чөлөөтэйгээр сонгоогүй гэж үү? Өөрийн бүтээлийн нэг болох чамаар Тэр үүнийг шийдүүлэх хэрэгтэй юу? Бурханыг

нэрлэдэг нэр нь хүний ойлгож чадах зүйлтэй, мөн хүн төрөлхтний хэлтэй нийцдэг нэр боловч энэ нэр бол хүний нэгтгэн дүгнэж чадах зүйл биш юм. Тэнгэрт нэг Бурхан байдаг, Түүнийг Бурхан гэж нэрлэдэг, Тэр бол агуу хүч чадалтай, маш ухаалаг, маш өргөмжит, тун гайхалтай, тун нууцлаг, үнэхээр төгс хүчит Бурхан Өөрөө юм гэж л чи хэлж чадна, тэгээд өөр юу ч хэлж чадахгүй; мэддэг бүхэн чинь ийм жаахан байдаг. Тийм болохоор ганцхан Есүсийн нэр Бурханыг Өөрийг нь төлөөлж чадах уу? Эцсийн өдрүүд ирэхэд Бурхан ажлаа хийж байгаа хэвээр хэдий ч Түүний нэр өөрчлөгдөх ёстой, учир нь энэ бол өөр эрин үе билээ.

Бурхан орчлон ертөнц даяар болон орчлон ертөнцийн дээр хамгийн агуу нь болохоор махбодын дүрийг ашиглаад Өөрийгөө бүрэн тайлбарлаж чадах уу? Бурхан ажлынхаа нэг үе шатыг хийхийн тулд энэ махбодыг өмсдөг. Махбодын энэ дүр төрхөд ямар ч онцгой утга учир байхгүй, энэ нь эрин үе өнгөрөхтэй ямар ч холбоогүй, мөн Бурханы зан чанартай ч хамаагүй. Яагаад Есүс Өөрийн дүр зургийг үлдээгээгүй вэ? Яагаад Тэр дараагийн үеийнхэнд дамжуулахын тулд хүнээр Өөрийнхөө дүрийг зуруулаагүй вэ? Түүний дүр төрх бол Бурханы дүр төрх гэдгийг Тэр яагаад хүмүүсээр хүлээн зөвшөөрүүлээгүй вэ? Хэдийгээр хүний дүр төрх Бурханы дүрээр бүтээгдсэн боловч хүний гадаад төрх нь Бурханы өргөмжит дүрийг төлөөлөх боломжтой гэж үү? Бурхан махбод болохдоо тодорхой нэг махбодод тэнгэрээс бууж ирсэн төдий юм. Түүний Сүнс махбодод бууж ирсэн ба махбодоор дамжуулан Тэр Сүнсний ажлыг хийдэг. Сүнс махбодоор илэрхийлэгдэж, Өөрийн ажлыг махбодоор хийдэг. Махбодоор хийгддэг ажил нь Сүнсийг бүрэн төлөөлдөг бөгөөд уг махбод ажлын төлөө байдаг боловч махбодын дүр төрх нь Бурханы Өөрийн жинхэнэ дүр төрхийг орлодог гэсэн үг биш; энэ нь Бурхан махбод болсны зорилго, ач холбогдол биш юм. Тэр махбод болсон болохоор л Сүнс Өөрийн ажилд тохирох оршин суух газрыг олж, махбод дахь ажлаа илүү сайн биелүүлж болох бөгөөд ингэснээр хүмүүс Түүний үйл хэргийг харж, Түүний зан чанарыг ойлгож, Түүний үгийг сонсож, Түүний ажлын гайхамшгийг мэдэж чадна. Түүний нэр зан чанарыг нь төлөөлдөг, Түүний ажил ялгамж чанарыг нь төлөөлдөг боловч махбодынх нь гадаад төрх Өөрийнх нь дүр төрхийг төлөөлдөг гэж Тэр хэзээ ч хэлээгүй; тэр нь ердөө л хүний үзэл юм. Иймээс бие махбодтой болсон Бурханы гол чухал талууд нь Түүний нэр, Түүний ажил, Түүний зан чанар болон Түүний хүйс билээ. Энэ эрин үе дэх Түүний удирдлагыг төлөөлөхөд эдгээр нь ашиглагддаг. Махбод дахь Түүний гадаад төрх нь Түүний удирдлагад ямар ч хамаагүй бөгөөд тухайн үеийн Түүний ажлын төлөө л байдаг. Гэсэн ч бие махбодтой болсон Бурханы хувьд ямар ч тодорхой гадаад төрхгүй байх боломжгүй тул Өөрийнх нь гадаад төрхийг шийдэх тохиромжтой гэр бүлийг Тэр сонгодог. Хэрвээ Бурханы гадаад төрх төлөөллийн ач холбогдолтой бол Түүнтэй төстэй царайтай бүх хүн ч бас Бурханыг төлөөлөх байсан. Тэгэх нь ноцтой алдаа байх бус уу? Хүнээр шүтүүлэхийн тулд Есүсийн хөргийг хүн зурсан. Тухайн үед Ариун Сүнс ямар ч онцгой удирдамж өгөөгүй тул хүн төсөөллийн тэрхүү хөрөг зургийг өнөөдрийг

хүртэл дамжуулсан юм. Үнэндээ Бурханы анхдагч санаа зорилгоор бол хүн ингэх ёсгүй байсан. Хүний хичээл зүтгэл л Есүсийн хөрөг зургийг өнөөдрийг хүртэл үлдээсэн юм. Бурхан бол Сүнс бөгөөд Түүний дүр төрх яг ямар болохыг хүн хэзээ ч нэгтгэн дүгнэж чадахгүй. Түүний дүр төрхийг Түүний зан чанар л төлөөлж чадна. Түүний хамар, ам, нүд, үсний харагдах байдлын тухайд бол эдгээр нь нэгтгэн дүгнэх чадвараас чинь давдаг. Иоханд илчлэл ирэх үед тэр хүний Хүүгийн дүрийг харсан: Түүний амнаас хоёр талдаа иртэй хурц сэлэм гарсан, нүд нь галын дөл шиг, толгой болон үс нь ноос шиг цагаан, хөл нь өнгөлсөн хүрэл шиг байсан ба Түүний цээжинд алтлаг тууз байв. Түүний үг туйлын тодорхой байсан хэдий ч түүний дүрсэлсэн Бурханы дүр төрх нь бүтээгдсэн зүйлийн дүр төрх байгаагүй юм. Түүний харсан зүйл ердөө л үзэгдэл байсан ба материаллаг ертөнцийн хүний дүр төрх биш байлаа. Иохан үзэгдэл харсан боловч Бурханы жинхэнэ төрхийг хараагүй. Бурханы махбод болсон биеийн дүр төрх нь бүтээгдсэн зүйлийн дүр болохоор Бурханы зан чанарыг бүхэлд нь төлөөлж чадахгүй. Ехова хүн төрөлхтнийг бүтээх үедээ Өөрийн дүрээр бүтээсэн гэж хэлсэн бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээсэн. Тухайн үед Тэр эрэгтэй, эмэгтэй хүнийг Бурханы дүрээр бүтээсэн гэж хэлсэн билээ. Хэдийгээр хүний дүр төрх Бурханы дүртэй төстэй боловч хүний гадаад төрх бол Бурханы дүр мөн гэсэн утгатай хэмээн тайлбарлаж болохгүй. Мөн Бурханы дүр төрхийг бүрэн илэрхийлэхийн тулд хүний хэлийг ашиглаж ч болохгүй, учир нь Бурхан маш өндөр дээд, маш агуу, тун гайхалтай агаад ойлгохын аргагүй билээ!

Есүс Өөрийн ажлыг хийхээр ирсэн нь Ариун Сүнсний зааварчилгааны дор явагдсан; Тэрээр Ариун Сүнсний хүссэн зүйлийг хийсэн бөгөөд энэ нь Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийн дагуу, эсвэл Еховагийн ажлын дагуу байгаагүй. Хэдийгээр Есүсийн хийхээр ирсэн ажил нь Еховагийн хууль, эсвэл Еховагийн тушаалуудыг мөрдөх явдал биш байсан ч Тэдний эх сурвалж ав адилхан байсан юм. Есүсийн хийсэн ажил Есүсийн нэрийг төлөөлж, Нигүүлслийн эрин үеийг төлөөлсөн; Еховагийн хийсэн ажлын тухайд бол энэ нь Еховаг төлөөлсөн бөгөөд Хуулийн эрин үеийг төлөөлсөн. Тэдний ажил бол хоёр өөр эрин үе дэх нэг Сүнсний ажил байсан юм. Есүсийн хийсэн ажил Нигүүлслийн эрин үеийг л төлөөлж чадсан бөгөөд Еховагийн хийсэн ажил зөвхөн Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийг л төлөөлж байв. Ехова зөвхөн Израиль, Египетийн ард түмэн болон Израилийн гаднах бүх үндэстний хүмүүсийг л удирдан чиглүүлсэн юм. Шинэ Гэрээний Нигүүлслийн эрин үе дэх Есүсийн ажил нь, эрин үеийг залж чиглүүлэнгээ Есүсийн нэрээр ажилласан Бурханы ажил байлаа. Хэрвээ чи, Есүсийн ажил нь Еховагийнх дээр суурилсан, Тэр ямар ч шинэ ажил эхлүүлээгүй, Түүний хийсэн бүхэн Еховагийн үгийн дагуу, Еховагийн ажлын дагуу, Исаиагийн зөгнөлийн дагуу байсан гэж хэлбэл Есүс махбод болсон Бурхан биш байх байв. Хэрвээ Тэр ийм маягаар ажлаа явуулсан бол Хуулийн эрин үеийн элч юм уу ажилчин байх байлаа. Хэрвээ чиний хэлдэг шиг байсан бол Есүс эрин үеийг эхлүүлж чадахгүй, өөр ямар ч ажил хийж чадахгүй байх байсан юм. Үүний адилаар, Ариун Сүнс Өөрийн ажлыг

үндсэндээ Еховагаар дамжуулан хийх ёстой ба Еховагаар дамжуулахгүй л бол Ариун Сүнс ямар ч шинэ ажил хийж чадахгүй байх байв. Хүн Есүсийн ажлыг ийм маягаар ойлгох нь буруу юм. Есүсийн хийсэн ажил Еховагийн үг болон Исаиагийн зөгнөлийн дагуу байсан гэж хүн итгэдэг бол Есүс бие махбодтой болсон Бурхан байсан уу, эсвэл эш үзүүлэгчдийн нэг байсан уу? Энэ үзэл бодлоор бол Нигүүлслийн эрин үе гэж байхгүй ба Есүс бие махбодтой болсон Бурхан биш байх байв, учир нь Түүний хийсэн ажил Нигүүлслийн эрин үеийг төлөөлж чадахгүй, харин Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийг л төлөөлж чадах байлаа. Есүс шинэ ажил хийхээр ирж, шинэ эрин үеийг эхлүүлж, урьд нь Израильд хийгдсэн ажлаас халин гарч, Өөрийн ажлыг Еховагийн Израильд хийсэн ажлын дагуу явуулалгүй, Түүний хуучин дүрэм журамд баригдалгүй, ямар ч ёс заншлыг дагалгүй, харин Өөрийн хийх ёстой шинэ ажлыг хийсэн үед л шинэ эрин үе бий болох байсан юм. Эрин үеийг эхлүүлэхийн тулд Бурхан Өөрөө ирдэг ба эрин үеийг төгсгөхийн тулд Бурхан Өөрөө ирдэг. Хүн эрин үеийг эхлүүлэх болон эрин үеийг төгсгөх ажлыг хийх чадваргүй. Хэрвээ Есүс ирснийхээ дараа Еховагийн ажлыг төгсгөөгүй бол Тэр ердөө хүн байсан ба Бурханыг төлөөлөх чадваргүй байсан гэдгийг энэ нь нотлох байв. Есүс ирж, Еховагийн ажлыг дуусгаж, Еховагийн ажлыг үргэлжлүүлж, улмаар Өөрийнхөө ажлыг буюу шинэ ажлыг гүйцэтгэсэн учраас л энэ бол шинэ эрин үе байсан бөгөөд Есүс бол Бурхан Өөрөө байсан гэдгийг энэ нь нотолдог. Тэд ажлын илт өөр хоёр үе шатыг гүйцэтгэсэн. Нэг үе шат нь сүмд явагдсан ба нөгөө нь сүмийн гадна хийгджээ. Нэг үе шат нь хуулийн дагуу хүний амьдралыг удирдан хөтлөх, харин нөгөө нь нүглийн тахил өргөхийн төлөө байв. Ажлын энэ хоёр үе шат харваас өөр байсан; энэ нь шинэ эрин үеийг хуучнаас салгадаг бөгөөд тэдгээр нь хоёр өөр эрин үе юм гэж хэлэх нь туйлын зөв. Тэдний ажлын байршил өөр байсан, ажлынх нь агуулга өөр байсан, ажлынх нь зорилго өөр байсан юм. Иймээс тэдгээрийг хоёр эрин үед хувааж болно: Шинэ ба Хуучин Гэрээ буюу шинэ ба хуучин эрин үе. Есүс ирэхдээ сүм рүү очоогүй нь Еховагийн эрин үе төгссөнийг нотолдог. Сүм дэх Еховагийн ажил дууссан, дахин хийх хэрэггүй байсан учраас Тэр сүмд ороогүй бөгөөд үүнийг дахин хийх нь давтаж байгаа хэрэг болох байв. Сүмийг орхин явж, сүмийн гадна шинэ ажил эхлүүлж, шинэ замыг нээснээр л Тэр Бурханы ажлыг дээд цэгт нь аваачиж чадах байлаа. Хэрвээ Тэр Өөрийн ажлыг хийхийн тулд сүмээс гараагүй бол Бурханы ажил сүмийн суурин дээр зогсож, ямар ч шинэ өөрчлөлт гарахгүй байх байв. Иймээс Есүс ирэх үедээ сүмд ороогүй ба Өөрийн ажлыг сүмд хийгээгүй юм. Тэрээр ажлаа сүмийн гадна хийж, шавь нараа дагуулан Өөрийн ажлыг чөлөөтэй хийж эхэлсэн билээ. Бурхан Өөрийн ажлыг хийхээр сүмээс явсан нь Бурханд шинэ төлөвлөгөө бий гэсэн утгатай байв. Түүний ажил сүмийн гадна явагдах ёстой байсан бөгөөд хэрэгжих байдлаараа хязгаарлагдахгүй шинэ ажил байх ёстой байлаа. Есүс ирмэгцээ Хуучин Гэрээний эрин үе дэх Еховагийн ажлыг төгсгөсөн юм. Хэдийгээр Тэднийг хоёр өөр нэрээр нэрлэж байсан ч ажлын хоёр үе шатыг хоёуланг нь нэг Сүнс хийсэн бөгөөд хийгдсэн ажил нь үргэлжилсэн ажил

байв. Нэр нь өөр байсны адилаар ажлын агуулга өөр, эрин үе өөр байсан. Еховаг ирэх үед тэр нь Еховагийн эрин үе байсан бөгөөд Есүсийг ирэх үед Есүсийн эрин үе байв. Иймээс ирэх болгондоо Бурхан нэг нэрээр нэрлэгдэж, нэг эрин үеийг төлөөлж, шинэ замыг нээдэг; шинэ зам болгонд Тэрээр шинэ нэр авдаг нь Бурхан үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй, Түүний ажил урагш ахихаа хэзээ ч больдоггүй гэдгийг харуулдаг. Түүх үргэлж урагшилж байгаа ба Бурханы ажил үргэлж урагшилж байгаа. Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө төгсгөлдөө хүрэхийн тулд ямагт урагшлан ахисаар байх ёстой. Өдөр бүр Тэр шинэ ажил хийх ёстой, жил болгон Тэр шинэ ажил хийх ёстой; Тэр шинэ замыг нээж, шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ, илүү агуу ажлыг эхлүүлж, эдгээрийн хамтаар шинэ нэр, шинэ ажлыг авчрах ёстой. Хором бүрд Бурханы Сүнс үргэлж шинэ ажил хийж байгаа ба хуучин арга зам, дүрэм журамтай хэзээ ч зууралддаггүй. Мөн Түүний ажил хэзээ ч зогсоогүй, харин хором мөч өнгөрөх бүрд хийгдсээр байгаа. Хэрвээ чи, Ариун Сүнсний ажил хэзээ ч хувиршгүй гэж хэлдэг бол, сүм дотор Өөрт нь үйлчлэхийг Ехова тахилчдаас шаардсан атал Есүсийг ирэх үед хүмүүс Түүнийг тэргүүн тахилч, Давидын гэрийн нэгэн, түүнчлэн тэргүүн тахилч, агуу Хаан гэж хэлж байсан ч Есүс яагаад сүмд ороогүй юм бэ? Яагаад Тэр тахил өргөөгүй вэ? Сүмд орсон ч бай, эсвэл үгүй ч бай—энэ нь бүгд Бурханы Өөрийн ажил биш гэж үү? Хэрвээ хүний төсөөлдгөөр Есүс дахин ирж, эцсийн өдрүүдэд Есүс гэж нэрлэгдсэн хэвээр байж, Есүсийн дүрээр хүмүүсийн дунд цагаан үүл хөлөглөн бууж ирсэн бол Түүний ажил давтагдсан хэрэг болох бус уу? Ариун Сүнс хуучин зүйлтэй зууралдаж чадах уу? Хүний боддог бүхэн нь үзэл бөгөөд хүний ойлгодог бүхэн нь үгчилсэн утгын дагуу, бас өөрсдийнх нь төсөөллийн дагуу байдаг; тэр нь Ариун Сүнсний ажлын зарчимтай тохирдоггүй бөгөөд Бурханы санаа зорилгод нийцдэггүй. Бурхан тийм маягаар ажиллахгүй; Бурхан тийм ч мунхаг, тэнэг биш бөгөөд Түүний ажил чиний төсөөлдөг шиг тийм энгийн биш. Хүмүүсийн төсөөлдөг бүхэнд үндэслэвэл Есүс үүл хөлөглөн ирж, та нарын дунд бууна. Үүл хөлөглөсөн Тэрээр Өөрийгөө Есүс мөн гэж хэлэхийг та нар харна. Та нар бас Түүний гар дахь хадаасны сорвийг олж хараад, Есүс мөн гэдгийг нь мэднэ. Тэрээр та нарыг дахин аварч, та нарын хүчирхэг Бурхан байх болно. Тэр та нарыг аварч, та нарт шинэ нэр хайрлаж, дор бүрд чинь цагаан чулуу өгнө, үүний дараа та нар тэнгэрийн хаанчлалд орох боломжтой болж, диваажин руу хүргэгдэнэ. Ийм итгэл нь хүний үзэл биш гэж үү? Бурхан хүний үзлийн дагуу ажилладаг уу, эсвэл хүний үзлийн эсрэг ажилладаг уу? Хүний бүх үзэл Сатанаас үүдэн гардаггүй гэж үү? Бүх хүнийг Сатан завхруулаагүй гэж үү? Хэрвээ Бурхан Өөрийн ажлыг хүний үзлийн дагуу хийсэн бол Сатан болчихгүй гэж үү? Тэр Өөрийнхөө бүтээлүүдтэй адил төрлийнх байх бус уу? Түүний бүтээлүүдийг одоо Сатан маш их завхруулж, хүн Сатаны биелэл болсон тул хэрвээ Бурхан, Сатаны зүйлсэд нийцүүлэн ажилласан бол Сатантай хуйвалдаж байгаа хэрэг болох бус уу? Хүн Бурханы ажлыг яаж ойлгож чадах юм бэ? Тиймээс Бурхан хэзээ ч хүний үзлийн дагуу ажиллахгүй, хэзээ ч чиний төсөөлдөг шигээр ажиллахгүй. Үүлэн дээр ирнэ

гэж Бурхан Өөрөө хэлсэн гэцгээдэг хүмүүс бий. Бурхан Өөрөө ингэж хэлсэн нь үнэн боловч Бурханы нууцыг нэг ч хүн ухан ойлгож чадахгүй гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Бурханы үгийг нэг ч хүн тайлбарлаж чадахгүй гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Ариун Сүнс чамайг гэгээрүүлж, гэрэлтүүлсэн гэдэгт чи өчүүхэн ч эргэлзэхгүйгээр итгэж байна уу? Мэдээж Ариун Сүнс чамд тийм шууд байдлаар харуулаагүй биз дээ? Үүнийг Ариун Сүнс зааварласан уу, эсвэл өөрийн чинь үзэл чамайг ингэж бодоход хүргэсэн үү? Чи: “Үүнийг Бурхан Өөрөө хэлсэн” гэсэн. Гэхдээ Бурханы үгийг хэмжихдээ бид өөрсдийн үзэл, оюун ухааныг ашиглаж болохгүй. Исаиагийн хэлсэн үгийн тухайд гэвэл, чи түүний үгийг туйлын итгэлтэйгээр тайлбарлаж чадах уу? Чи түүний үгийг тайлбарлаж зүрхлэх үү? Чи Исаиагийн үгийг тайлбарлаж зүрхлэхгүй юм бол яагаад Есүсийн үгийг тайлбарлаж зүрхэлдэг юм бэ? Есүс, Исаиа хоёрын хэн нь илүү өндөр дээд вэ? Хариулт нь Есүс байхад чи яагаад Есүсийн хэлсэн үгийг тайлбарладаг юм бэ? Бурхан Өөрийнхөө ажлын талаар чамд урьдчилан хэлэх үү? Ганц ч бүтээгдсэн зүйл, бүр тэнгэр дэх элчүүд, хүний Хүү ч мэдэж чадахгүй, тэгвэл чи яаж мэдэж чадах юм бэ? Хүн хэтэрхий дутуу дулимаг. Одоо чиний хувьд хамгийн чухал зүйл бол ажлын гурван үе шатыг мэдэх явдал юм. Еховагийн ажлаас Есүсийнхийг хүртэл, Есүсийн ажлаас одоогийн энэ үе шатны ажил хүртэлх энэ гурван үе шат тасралтгүй уялдаатайгаар Бурханы удирдлагын бүхий л цар хүрээг хамардаг ба бүгдээрээ нэг Сүнсний ажил юм. Дэлхий ертөнцийн бүтээлээс хойш Бурхан үргэлж хүн төрөлхтнийг удирдан ажилласаар ирсэн. Тэр бол Эхлэл ба Төгсгөл, Эхэн ба Эцэс, эрин үеийг эхлүүлдэг Нэгэн, бас эрин үеийг төгсгөдөг Нэгэн юм. Өөр өөр эрин үе, өөр өөр байршил дахь ажлын гурван үе шат нь гарцаагүй нэг Сүнсний ажил мөн. Энэ гурван үе шатыг хуваадаг бүх хүн Бурханыг эсэргүүцэн зогсдог. Эхний үе шатнаас өнөөдрийг хүртэлх бүх ажил нь нэг Бурханы ажил, нэг Сүнсний ажил юм гэдгийг одоо чи ойлговол зохино. Үүнд эргэлзэх юмгүй.

БИБЛИЙН ТАЛААР 1

Бурханд итгэхдээ Библид хэрхэн хандах ёстой вэ? Энэ бол зарчмын асуулт юм. Яагаад бид энэ асуултыг ярилцаж байна вэ? Учир нь ирээдүйд чи сайн мэдээг түгээж, Хаанчлалын эрин үеийн ажлыг өргөжүүлэх бөгөөд Бурханы өнөөдрийн үгийг зүгээр л ярьж чаддаг байх нь хангалтгүй юм. Түүний ажлыг өргөжүүлэхийн тулд чи хүмүүсийн шашны хуучин үзэл болон итгэл бишрэлийн хуучин арга барилыг шийдвэрлэж, тэднийг бүрэн үнэмшүүлж чаддаг байх нь илүү чухал бөгөөд тухайн цэгт хүрэх нь Библитэй холбоотой. Олон жилийн турш хүмүүсийн итгэлийн (дэлхийн гурван гол шашны нэг болох Христийн шашны) уламжлалт арга барил нь Библийг унших явдал байсан; Библиэс холдох нь Эзэнд итгэх итгэл биш, Библиэс холдох нь буруу ном, тэрс үзэл бөгөөд хүмүүс өөр ном уншиж байхад ч гэсэн, эдгээр номын үндэс суурь нь Библийн тайлбар байх ёстой. Өөрөөр хэлбэл, хэрвээ

чи Эзэнд итгэдэг бол Библийг унших ёстой бөгөөд Библиэс гадна Библитэй холбоогүй ямар ч номыг шүтэх ёсгүй. Хэрвээ шүтвэл чи Бурханаас урваж байна. Библи байсан үеэс эхлээд Эзэнд итгэх хүмүүсийн итгэл нь Библид итгэх итгэл байсаар ирсэн. Хүмүүс Эзэнд итгэдэг гэж хэлэхийн оронд тэд Библид итгэдэг гэж хэлсэн нь дээр; тэд Библийг уншиж эхэлсэн гэж хэлэхийн оронд тэд Библид итгэж эхэлсэн гэж хэлсэн нь дээр; тэд Эзэний өмнө эргэн очсон гэж хэлэхийн оронд Библийн өмнө эргэн очсон гэж хэлсэн нь дээр. Ийм маягаар хүмүүс Библийг Бурхан мэт, мөн өөрсдийнх нь амийн эх булаг шиг шүтсэн ба үүнийг алдах нь амиа алдахтай адил байв. Хүмүүс Библийг Бурхантай адил өндөр дээд гэж үздэг ба Бурханаас дээгүүрт үздэг хүмүүс ч бий. Хүмүүс Ариун Сүнсний ажилгүй бол, Бурханыг мэдэрч чаддаггүй бол амьдарсаар байж чадах боловч Библийг алдах юм уу Библийн алдартай бүлэг болон үгийг алдмагцаа амиа алдсантай адил болдог. Иймээс хүмүүс Эзэнд итгэж эхэлмэгцээ Библийг уншиж, Библийг цээжилж эхэлдэг бөгөөд Библийг хэдий чинээ их цээжилж чадна, энэ нь Эзэнийг хайрладаг, агуу итгэлтэй гэдгийг нь төдий чинээ их нотолдог. Библийг уншсан, мөн үүний талаар бусдад ярьж чаддаг хүмүүс бол бүгд сайн ах эгч нар юм. Энэ бүх жилүүдэд хүмүүсийн Эзэнд итгэх итгэл, үнэнч байдал Библийг хэр ойлгодгоор нь хэмжигдсээр ирсэн. Ихэнх хүмүүс Бурханд яагаад итгэх ёстойгоо, эсвэл Бурханд хэрхэн итгэх ёстойгоо ч ер ойлгодоггүй бөгөөд Библийн бүлгүүдийг тайлж унших сэжүүрийг сохроор хайхаас өөрийг хийдэггүй. Хүмүүс Ариун Сүнсний ажлын чиглэлийг хэзээ ч эрэлхийлж байгаагүй; бүр анхнаасаа л тэд Библийг цөхрөнгөө баран судалж, шинжилсэн ба Библийн гаднах Ариун Сүнсний илүү шинэлэг ажлыг хэн ч, хэзээ ч олоогүй. Хэн ч, хэзээ ч Библиэс холдоогүй, хэзээ ч тэгж зүрхлээгүй. Хүмүүс энэ бүх жилүүдэд Библийг судалж, маш олон тайлбаруудыг гарган ирж, маш их чармайлт гаргасан; бас тэдэнд Библийн талаар олон өөр санал бодол байдаг бөгөөд тэд тасралтгүй мэтгэлцдэг болохоор өнөөдөр хоёр мянга гаруй өөр урсгал бий болсон юм. Тэд бүгдээрээ ямар нэг онцгой тайлбарыг, эсвэл Библи дэх илүү гүн гүнзгий нууцуудыг олохыг хүсдэг, мөн үүнийг судалж шинжлэн, Израиль дахь Еховагийн ажлын цаад учир, Иудей дэх Есүсийн ажлын цаад учир, эсвэл хэний ч мэддэггүй илүү олон нууцыг олохыг хүсдэг. Библид хандах хүмүүсийн хандлага нь донтолт, итгэлийн байдалтай байдаг бөгөөд Библийн дотоод түүх юм уу мөн чанарын талаар хэн ч бүрэн дүүрэн ойлгож чаддаггүй. Иймээс Библийн тухайд гэвэл, өнөөдөр ч хүмүүс дүрслэн хэлэхийн аргагүй гайхсан мэдрэмжтэй байдаг бөгөөд үүнд улам их донтож, улам их итгэдэг. Өнөөдөр хүн бүхэн Библиэс эцсийн өдрүүдийн ажлын тухай зөгнөлүүдийг олохыг хүсдэг, мөн эцсийн өдрүүдэд Бурхан ямар ажил хийдгийг болон эцсийн өдрүүдийн ямар тэмдгүүд байдгийг олж мэдэхийг хүсдэг. Ийм маягаар Библийг шүтэх нь илүү оргилуун болдог ба эцсийн өдрүүд ойртох тусам тэд ялангуяа эцсийн өдрүүдийн талаарх Библийн зөгнөлүүдэд төдий чинээ сохроор итгэдэг. Библид ийнхүү сохроор итгэснээр, Библид ингэж их найдсанаар тэд Ариун Сүнсний ажлыг эрж хайх ямар ч хүсэлгүй байдаг.

Өөрсдийнхөө үзлээр хүмүүс Библи л Ариун Сүнсний ажлыг авчирч чадна гэж боддог; мөн Библиэс л Бурханы мөрийг олж чадна; Бурханы ажлын нууцууд зөвхөн Библид л нуугдаж байдаг; өөр ном юм уу хүмүүс биш, зөвхөн Библи л Бурханы талаарх бүх зүйлийг болон Түүний ажлыг бүхэлд нь тодруулж чадна; Библи тэнгэрийн ажлыг газарт авчирч чадна; Библи нь эрин үеүдийг эхлүүлж, бас төгсгөж чадна гэж боддог. Ийм үзэлтэй болохоор хүмүүст Ариун Сүнсний ажлыг эрж хайх ямар ч дур сонирхол байдаггүй. Иймээс урьд нь Библи хүмүүст хэр их тус болж байсан нь хамаагүй, энэ нь Бурханы хамгийн сүүлийн үеийн ажилд саад тотгор болсон юм. Библигүй бол хүмүүс Бурханы мөрийг өөр хаа нэгтэйгээс хайх байсан атал өнөөдөр Түүний мөр Библиэр хязгаарлагдаж, Түүний хамгийн сүүлийн үеийн ажлыг өргөжүүлэх нь хоёр дахин их хэцүү, бэрхшээлтэй тэмцэл болсон билээ. Энэ нь бүхэлдээ Библийн алдартай бүлэг болон үгсээс, түүнчлэн Библийн олон янзын зөгнөлүүдээс болдог. Библи хүмүүсийн сэтгэл дэх шүтээн болж, тэдний уураг тархин дахь таавар болсон бөгөөд тэд ердөө Бурхан Библиэс гадна ажиллаж чадна гэж итгэх чадваргүй, хүмүүс Бурханыг Библийн гаднаас олж чадна гэж итгэх чадваргүй, тэр ч бүү хэл сүүлчийн ажлын үеэр Бурхан Библийг орхиж, шинээр эхэлж чадна гэдэгт ч итгэж чаддаггүй. Энэ нь хүмүүсийн хувьд санаанд оромгүй зүйл; тэд үүнд итгэж чадахгүй, үүнийг төсөөлж ч чадахгүй. Хүмүүс Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөхөд Библи томоохон саад тотгор болсон бөгөөд Бурхан энэ шинэ ажлыг өргөжүүлэхэд бэрхшээл учруулсан. Тиймээс хэрвээ та нар Библийн дотоод түүхийг ойлгодоггүй бол сайн мэдээг амжилттай түгээж чадахгүй, шинэ ажилд гэрчлэл хийж ч чадахгүй. Хэдийгээр өнөөдөр та нар Библийг уншдаггүй ч үүнд туйлын нөхөрсөг ханддаг, өөрөөр хэлбэл, гарт чинь Библи байхгүй байж болох ч та нарын ихэнх үзэл үүнээс гарч ирдэг. Та нар Библийн эх сурвалжийг, эсвэл Бурханы ажлын урьдын хоёр үе шатны тухай дотоод түүхийг ойлгодоггүй. Хэдийгээр та нар Библийг үргэлж уншдаггүй ч Библийг ойлгох ёстой, Библийн талаар зөв мэдлэгтэй болох ёстой, ийм маягаар л та нар Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гэж юу болохыг мэдэж чадна. Тэгээд хүмүүсийг ятгаж, энэ урсгал бол үнэн зам гэдгийг тэднээр хүлээн зөвшөөрүүлж, өнөөдөр алхдаг зам чинь үнэний зам бөгөөд үүнийг Ариун Сүнс залж чиглүүлдэг, ямар ч хүн үүнийг үүсгэн санаачлаагүй гэдгийг хүлээн зөвшөөрүүлэхийн тулд эдгээр зүйлийг ашиглана.

Бурхан Хуулийн эрин үеийн ажлыг хийсны дараа Хуучин Гэрээ бий болсон бөгөөд тэр үед хүмүүс Библийг уншиж эхэлсэн юм. Есүс ирснийхээ дараа Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийж, элч нар нь Шинэ Гэрээг бичжээ. Тийнхүү Библийн Хуучин болон Шинэ Гэрээ бий болсон бөгөөд бүр өнөөг хүртэл, Бурханд итгэдэг бүх хүн Библийг уншсаар ирсэн. Библи бол түүхийн ном юм. Мэдээж энэ нь бас эш үзүүлэгчдийн зарим зөгнөлийг агуулдаг бөгөөд эдгээр зөгнөл яавч түүх биш. Библи хэд хэдэн хэсгийг агуулдаг—үүнд зөвхөн зөгнөл байдаггүй, эсвэл зөвхөн Еховагийн ажил, бас зөвхөн Паулын захидлууд байдаггүй. Библи хэдэн хэсгийг

агуулдгийг чи мэдэх ёстой; Хуучин Гэрээ нь Эхлэл, Гэтлэл … зэргийг багтаадаг ба бас эш үзүүлэгчдийн бичсэн зөгнөлийн номууд байдаг. Эцэстээ Хуучин Гэрээ нь Малахийн Номоор төгсдөг. Энэ нь Еховагийн удирдсан Хуулийн эрин үеийн ажлыг тэмдэглэсэн байдаг; Эхлэлээс эхлээд Малахийн Ном хүртэл энэ нь Хуулийн эрин үеийн бүх ажлын иж бүрэн тэмдэглэл юм. Өөрөөр хэлбэл, Хуучин Гэрээ нь Хуулийн эрин үед Еховагаар удирдуулж байсан хүмүүсийн туулсан бүхнийг тэмдэглэсэн байдаг. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед Еховагийн өргөсөн асар олон тооны эш үзүүлэгч Түүний зөгнөлийг хэлж, янз бүрийн овог аймаг, улс үндэстэнд заавар өгч, Еховагийн хийх ажлыг зөгнөсөн юм. Өргөгдсөн энэ хүмүүст бүгдэд нь Ехова зөгнөлийн Сүнсийг өгчээ: Тэд Еховагаас ирсэн үзэгдлүүдийг харж, Түүний дуу хоолойг сонсож чаддаг байсан ба ийнхүү тэд Түүний онгодыг хүртэж, зөгнөл бичсэн. Тэдний хийсэн ажил Еховагийн дуу хоолойн илэрхийлэл, Еховагийн зөгнөлийн илэрхийлэл байсан бөгөөд тухайн үеийн Еховагийн ажил нь ердөө Сүнсийг ашиглан хүмүүсийг залж чиглүүлэх явдал байв; Тэрээр махбод болоогүй ба хүмүүс Түүний царайг огт хараагүй юм. Тиймээс Тэр Өөрийн ажлыг хийхийн тулд олон эш үзүүлэгчийг өргөж, тэдэнд зөн билгүүдийг өгснөөр тэд үүнийг Израилийн бүх овог, урагт дамжуулжээ. Тэдний ажил нь зөгнөл хэлэх явдал байсан ба тэдний зарим нь бусдад харуулахын тулд өөрсдөд нь өгсөн Еховагийн удирдамжуудыг бичиж тэмдэглэсэн. Ехова, зөгнөл хэлж, ирээдүйн ажил юм уу тухайн үед хийгдэх учиртай байсан ажлыг зөгнөг гэж энэ хүмүүсийг өргөсөн, ингэснээр хүмүүс Еховагийн гайхалтай байдал болон мэргэн ухааныг харж чадах байсан юм. Зөгнөлийн эдгээр ном нь Библийн бусад номоос нэлээд өөр; тэдгээр нь зөгнөлийн Сүнс өгөгдсөн хүмүүсийн буюу Еховагаас үзэгдэл юм уу дуу хоолой олж авсан хүмүүсийн ярьсан, бичсэн үгс байв. Зөгнөлийн номуудаас гадна Хуучин Гэрээн дэх бусад бүх зүйл нь Еховаг ажлаа дуусгасны дараа хүмүүсийн хийсэн тэмдэглэл юм. Эхлэл болон Гэтлэлийг Исаиагийн Ном болон Даниелийн Номтой харьцуулж болохгүйн адилаар эдгээр ном нь Еховагийн өргөсөн эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлийг орлож чадахгүй. Ажил хийгдэхээс өмнө зөгнөлүүд хэлэгдсэн; харин бусад ном нь ажил дууссаны дараа бичигдсэн бөгөөд хүмүүс үүнийг хийх чадвартай байлаа. Тухайн үеийн эш үзүүлэгчдэд Еховагийн онгод өгөгдөж, зарим зөгнөлийг хэлсэн ба тэд олон үг хэлж, Нигүүлслийн эрин үеийн зүйлсийг болон Еховагийн хийхээр төлөвлөсөн ажил буюу эцсийн өдрүүд дэх дэлхийн сүйрлийг зөгнөсөн. Үлдсэн ном нь бүгд Израильд Еховагийн хийсэн ажлыг тэмдэглэсэн байдаг. Тиймээс Библийг унших үедээ чи ерөнхийдөө Израильд хийсэн Еховагийн ажлын тухай уншиж байгаа юм; Библийн Хуучин Гэрээ нь үндсэндээ Израилийг удирдан чиглүүлсэн Еховагийн ажил болон израильчуудыг Египетээс удирдан гаргахад Мосег хэрэглэснийг нь тэмдэглэсэн байдаг бөгөөд Мосе израильчуудыг Фараоны дөнгөнөөс чөлөөлж, цөлд аваачин, улмаар тэд Канаанд орсноор үүний дараа болсон бүхэн нь Канаан дахь тэдний амьдрал байсан. Үүнээс бусад бүх зүйл нь Израиль даяарх Еховагийн ажлын тэмдэглэлүүд юм. Хуучин Гэрээнд бичигдсэн

бүхэн нь Израиль дахь Еховагийн ажил, Адам Еваг бүтээсэн газар нутагт хийсэн Еховагийн ажил билээ. Ноагийн дараа Бурхан албан ёсоор газар дээрх хүмүүсийг удирдаж эхэлсэн үеэс эхлээд Хуучин Гэрээнд бичигдсэн бүхэн нь Израилийн ажил билээ. Тэгвэл яагаад Израилийн гаднах өөр ямар нэг ажил тэмдэглэгдээгүй вэ? Учир нь Израилийн газар нутаг бол хүн төрөлхтний өлгий юм. Эхэндээ Израилиас өөр ямар ч улс орон байгаагүй ба Ехова өөр ямар нэгэн газарт ажиллаагүй. Ийм маягаар, Библийн Хуучин Гэрээнд бичигдсэн зүйлс нь гагцхүү тухайн үеийн Израиль дахь Бурханы ажил юм. Эш үзүүлэгчид, Исаиа, Даниел, Иеремиа болон Езекиелийн хэлсэн үг … тэдний үг газар дээрх Түүний бусад ажлыг зөгнөсөн, тэд Ехова Бурханы Өөрийн ажлыг зөгнөсөн. Энэ бүхэн нь Бурханаас ирсэн, Ариун Сүнсний ажил байсан ба эш үзүүлэгчдийн эдгээр номоос гадна бусад бүх зүйл нь тэр үеийн Еховагийн ажлыг туулсан хүмүүсийн тэмдэглэл юм.

Бүтээлийн ажил нь хүн төрөлхтөн бий болохоос өмнө тохиолдсон, харин Эхлэлийн Ном нь хүн төрөлхтөн бий болсны дараа л гарч ирсэн; энэ нь Хуулийн эрин үед Мосегийн бичсэн ном байлаа. Энэ нь өнөөдөр та нарын дунд тохиолдож буй зүйлстэй адилхан: Тэдгээрийг тохиолдсоны дараа та нар хойч үеийн хүмүүст харуулахын тулд бичиж тэмдэглэдэг, та нарын тэмдэглэсэн зүйлс бол өнгөрсөн үед тохиолдсон зүйл—тэдгээр нь түүхээс цаашгүй. Хуучин Гэрээнд тэмдэглэгдсэн зүйлс нь Израиль дахь Еховагийн ажил бөгөөд Шинэ Гэрээнд тэмдэглэгдсэн байдаг зүйл нь Нигүүлслийн эрин үе дэх Есүсийн ажил юм; тэдгээр нь хоёр өөр эрин үед Бурханы хийсэн ажлыг баримтжуулдаг. Хуучин Гэрээ нь Хуулийн эрин үе дэх Бурханы ажлыг баримтжуулдаг, тиймээс Хуучин Гэрээ нь түүхэн ном, харин Шинэ Гэрээ нь Нигүүлслийн эрин үеийн ажлын үр дүн юм. Шинэ ажил эхлэх үед Шинэ Гэрээ ч бас хуучирсан—тиймээс Шинэ Гэрээ ч бас түүхэн ном юм. Мэдээж Шинэ Гэрээ нь Хуучин Гэрээ шиг эмх цэгцтэй биш, мөн үүн шиг олон зүйлийг ч бичээгүй. Еховагийн хэлсэн олон үг бүгдээрээ Библийн Хуучин Гэрээнд бичигдсэн байхад Есүсийн үгийн зарим нь л Дөрвөн Сайн Мэдээнд тэмдэглэгдсэн. Мэдээж Есүс бас маш их ажил хийсэн боловч үүнийг дэлгэрэнгүй бичээгүй. Шинэ Гэрээнд тийм бага зүйл бичигдсэн нь Есүсийн хийсэн ажлын хэмжээнээс болсон; газар дээрх гурван жил хагасын хугацаандаа Түүний хийсэн ажлын хэмжээ болон элчүүдийн ажил Еховагийн ажлаас хамаагүй бага байсан юм. Тиймээс Шинэ Гэрээнд Хуучин Гэрээнээс цөөхөн ном байдаг.

Библи чухамдаа ямар ном бэ? Хуучин Гэрээ бол Хуулийн эрин үе дэх Бурханы ажил юм. Библийн Хуучин Гэрээ нь Хуулийн эрин үе дэх Еховагийн бүх ажил болон Түүний бүтээлийн ажлыг тэмдэглэсэн байдаг. Энэ нь бүхэлдээ Еховагийн хийсэн ажлыг бичсэн байдаг ба эцэст нь Малахийн Номоор Еховагийн ажлын тухай тэмдэглэлийг төгсгөдөг. Хуучин Гэрээ нь Бурханы хийсэн ажлын хоёр хэсгийг тэмдэглэсэн байдаг: Нэг нь бүтээлийн ажил, нөгөө нь хууль гаргах явдал юм. Аль аль нь Еховагийн хийсэн ажил байсан. Хуулийн эрин үе нь Ехова Бурханы нэрийн доорх ажлыг төлөөлдөг; энэ нь үндсэндээ Еховагийн нэрийн дор хийгдсэн ажил

бүхэлдээ юм. Тиймээс Хуучин Гэрээ нь Еховагийн ажлыг тэмдэглэсэн ба Шинэ Гэрээ нь Есүсийн ажлыг буюу голчлон Есүсийн нэрийн дор хийгдсэн ажлыг бичсэн. Есүсийн нэрийн ач холбогдол болон Түүний хийсэн ажил ихэвчлэн Шинэ Гэрээнд бичигдсэн. Хуучин Гэрээний Хуулийн эрин үед Ехова Израильд ариун сүм болон тахилын ширээ барьж, газар дээрх израильчуудын амьдралыг залж чиглүүлж, тэд бол Түүний сонгосон хүмүүс, газар дээр Түүний сонгосон, Түүний зүрх сэтгэлийн дагуу байдаг эхний бүлэг хүмүүс, Түүний биечлэн удирдсан эхний бүлэг хүмүүс гэдгийг нотолсон юм. Израилийн арван хоёр овог нь Еховагийн анх сонгосон хүмүүс байсан тул Хуулийн эрин үеийн ажил нь төгсөх хүртэл Ехова үргэлж тэдний дунд ажилласан. Ажлын хоёр дахь үе шат нь Шинэ Гэрээний Нигүүлслийн эрин үеийн ажил байсан ба энэ нь Израилийн арван хоёр овгийн нэг болох иудей хүмүүсийн дунд хийгджээ. Есүс махбодтой болсон Бурхан байсан учраас ажлын цар хүрээ нь илүү бага байсан юм. Есүс Иудейн газар нутаг даяар л ажилласан ба гурван жил хагасын л ажил хийсэн; тиймээс Шинэ Гэрээнд бичигдсэн зүйл Хуучин Гэрээнд тэмдэглэгдсэн ажлын хэмжээг давж ер чадахааргүй байв. Нигүүлслийн эрин үеийн Есүсийн ажил нь үндсэндээ Дөрвөн Сайн Мэдээнд тэмдэглэгдсэн. Нигүүлслийн эрин үеийн хүмүүсийн алхсан зам нь тэдний амь зан чанар дахь хамгийн өнгөц өөрчлөлтийн зам байсан бөгөөд үүний ихэнхийг захидлуудад тэмдэглэсэн байдаг. Тухайн үед Ариун Сүнс хэрхэн ажиллаж байсныг захидлууд харуулдаг. (Мэдээж, гэсгээгдэж, золгүй явдалд өртсөнөөс үл хамааран, Паул хийсэн ажилдаа Ариун Сүнсээр зааварчлуулж байсан, тэрээр тухайн үед Ариун Сүнсний ашиглаж байсан хүн байв; Петрийг ч гэсэн Ариун Сүнс ашиглаж байсан, гэхдээ тэр Паул шиг их ажил хийгээгүй. Хэдийгээр Паулын ажил хүний хольц агуулж байсан ч тухайн үед Ариун Сүнс хэрхэн ажиллаж байсныг Паулын бичсэн захидлуудаас харж болно; Паулын хөтөлсөн зам зөв байсан, энэ нь зөв зүйтэй байсан бөгөөд Ариун Сүнсний зам байсан юм.)

Хэрвээ чи Хуулийн эрин үеийн ажлыг харж, израильчууд Еховагийн замыг хэрхэн дагасныг харахыг хүсвэл Хуучин Гэрээг унших ёстой; хэрвээ чи Нигүүлслийн эрин үеийн ажлыг ойлгохыг хүсвэл Шинэ Гэрээг унших ёстой. Гэхдээ чи эцсийн өдрүүдийн ажлыг хэрхэн харж байна вэ? Чи өнөөдрийн Бурханы удирдамжийг хүлээн зөвшөөрч, өнөөдрийн ажилд орох ёстой, учир нь энэ бол шинэ ажил бөгөөд хэн ч үүнийг өмнө нь Библид бичээгүй. Өнөөдөр Бурхан махбод болж, Хятад дахь өөр сонгогдсон хүмүүсийг шилж авсан. Бурхан энэ хүмүүс дээр ажиллаж, газар дээрх Өөрийн ажлыг үргэлжлүүлж, Нигүүлслийн эрин үеийн ажлаас үргэлжлүүлэн хийдэг. Өнөөдрийн ажил бол хүний хэзээ ч алхаж байгаагүй зам, хэн ч өмнө нь хараагүй зам билээ. Энэ нь урьд нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажил—газар дээрх Бурханы хамгийн сүүлийн үеийн ажил юм. Тиймээс өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажил бол түүх биш, учир нь одоо үе бол одоо бөгөөд хараахан өнгөрсөн үе болоогүй. Бурхан илүү агуу зүйлийг, газар дээрх илүү шинэлэг ажлыг Израилийн гадна хийснийг, мөн энэ нь аль хэдийн Израилийн цар хүрээнээс, эш

үзүүлэгчдийн зөгнөлөөс даван гарсан ба зөгнөлүүдийн гаднах шинэ, гайхамшигтай ажил, Израилиас давсан илүү шинэлэг ажил, хүмүүсийн ойлгож ч, төсөөлж ч чадахгүй ажил юм гэдгийг хүмүүс мэддэггүй. Ийм ажлын тухай илэн далангүй тэмдэглэлийг Библи яаж агуулж чадах билээ? Хэн өнөөгийн ажлыг нэг бүрчлэн, юу ч үлдээлгүйгээр урьдчилан тэмдэглэж чадах билээ? Тогтсон ёсыг зөрчдөг, энэхүү илүү хүчирхэг, илүү ухаалаг ажлыг хэн салбайсан хуучин номд тэмдэглэж чадах вэ? Өнөөдрийн ажил бол түүх биш, иймээс хэрвээ чи өнөөдрийн шинэ замаар алхахыг хүсвэл Библийг орхих ёстой, мөн зөгнөлийн ном, эсвэл Библи дэх түүхийг даван гарах ёстой. Зөвхөн тэр үед л чи шинэ замаар зүй зохистой алхаж чадна, тэр үед л чи шинэ ертөнцөд, шинэ ажилд орж чадна. Өнөөдөр яагаад чамаас Библи уншихгүй байхыг шаардаж байгааг, яагаад Библиэс тусдаа өөр ажил байгааг, яагаад Бурхан Библиэс илүү шинэ, илүү дэлгэрэнгүй хэрэгжүүлэлтийг хайдаггүйг, яагаад Библийн гаднах илүү хүчирхэг ажил байдгийг чи ойлгох ёстой. Та нарын ойлгох ёстой бүхэн энэ юм. Чи хуучин, шинэ ажлын хоорондох ялгааг мэдэх ёстой бөгөөд Библийг уншдаггүй байсан ч үүнийг задлан шинжилж чаддаг байх ёстой; тэгэхгүй бол чи Библийг шүтсээр л байх болно, улмаар шинэ ажилд орж, шинэ өөрчлөлтүүдийг туулахад хэцүү байх болно. Илүү өндөр зам байхад яагаад тэр хуучирсан, дорд замыг судална гэж? Илүү шинэлэг айлдвар, илүү шинэлэг ажил байхад яагаад хуучны түүхэн тэмдэглэл дунд амьдарна гэж? Шинэ айлдарууд чамайг хангадаг ба шинэ ажил мөн гэдгийг энэ нь баталдаг; хуучин тэмдэглэлүүд сэтгэлийг чинь хангаж чадахгүй, эсвэл одоогийн хэрэгцээг чинь хангаж чадахгүй бөгөөдөнөө үеийн ажил биш, түүх гэдгийг нь нотолдог. Хамгийн өндөр зам бол хамгийн шинэлэг ажил юм, мөн шинэ ажил байгаа болохоор өнгөрсөн үеийн зам хэчнээн өндөр байлаа ч энэ нь хүмүүсийн эргэн дурсах түүх төдий бөгөөд лавлах үнэ цэн нь ямар ч байлаа гэсэн, энэ нь мөн л хуучин зам юм. Хэдийгээр энэ нь “ариун номд” бичигдсэн ч хуучин зам бол түүх; харин үүний талаарх тэмдэглэл “ариун номд” байхгүй ч шинэ зам бол одоо үеийнх. Энэ зам чамайг аварч чадна, энэ зам чамайг өөрчилж чадна, учир нь энэ бол Ариун Сүнсний ажил билээ.

Та нар Библийг ойлгох ёстой—энэ ажил зайлшгүй шаардлагатай! Өнөөдөр чи Библи унших хэрэггүй, учир нь үүнд ямар ч шинэ зүйл байхгүй; энэ нь бүхэлдээ хуучирсан. Библи бол түүхэн ном бөгөөд хэрвээ чи Нигүүлслийн эрин үед Хуучин Гэрээг идэж, уусан бол—хэрвээ чи Хуучин Гэрээний үед шаардагдаж байсан зүйлсийг Нигүүлслийн эрин үед хэрэгжүүлсэн бол—Есүс чамайг голж, яллах байлаа; хэрвээ чи Есүсийн ажилд Хуучин Гэрээг хэрэглэсэн бол фарисай байх байсан. Хэрвээ өнөөдөр Хуучин ба Шинэ Гэрээг хамтад нь идэж ууж, хэрэгжүүлбэл өнөөдрийн Бурхан чамайг яллана; чи Ариун Сүнсний өнөөдрийн ажлаас хоцорсон байх болно! Хэрвээ чи Хуучин болон Шинэ Гэрээг идэж уудаг бол Ариун Сүнсний урсгалын гадна байна! Есүсийн цаг үед, Есүс Өөрт нь байсан Ариун Сүнсний ажлын дагуу иудейчүүд болон Өөрийг нь дагаж байсан хүмүүсийг удирдсан. Тэрээр Библийг Өөрийн хийсэн зүйлийн суурь болгоогүй, харин Өөрийн ажлын дагуу үгээ

хэлсэн; Библид хэлсэн байдаг зүйлд Тэр ямар ч анхаарал хандуулаагүй, дагалдагчдаа удирдах замыг ч Библиэс хайгаагүй. Ажиллаж эхэлсэн үеэсээ л Тэр гэмшлийн замыг түгээсэн ба Хуучин Гэрээний зөгнөлүүдэд тэрхүү үгийг огтхон ч дурдаагүй. Тэр Библийн дагуу үйлдээгүйгээр барахгүй, мөн шинэ замаар замнаж, шинэ ажил хийсэн. Тэр тунхаглах үедээ хэзээ ч Библиэс лавлаагүй. Хуулийн эрин үед, өвчтэйг эдгээх, чөтгөрийг зайлуулах Түүний гайхамшгуудыг хэн ч гүйцэтгэж чадаагүй. Иймээс Түүний ажил, Түүний сургаал болон Түүний үгийн эрх мэдэл, хүч чадалд Хуулийн эрин үеийн ямар ч хүн хүршгүй байлаа. Есүс ердөө л илүү шинэлэг ажлаа хийсэн ба олон хүн Библийг ашиглан Түүнийг яллаж байсан ч, бүр Түүнийг цовдлохын тулд Хуучин Гэрээг ашиглаж байсан ч Түүний ажил Хуучин Гэрээнээс давсан; ийм л биш бол яагаад хүмүүс Түүнийг загалмайд цовдолсон бэ? Энэ нь, Хуучин Гэрээнд Түүний сургаалын талаар, мөн өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах чадварынх нь талаар юу ч хэлээгүйгээс болоогүй гэж үү? Түүний ажил шинэ замаар хөтлөхийн тулд хийгдсэн, энэ нь санаатайгаар Библийн эсрэг тэмцэхийн тулд, эсвэл Хуучин Гэрээнээс зориуд ангижрахын тулд байгаагүй. Тэр зүгээр л үйлчлэлээ хэрэгжүүлэхийн тулд, Өөрийг нь хүсэн эрмэлзэж, эрж хайж байсан хүмүүст шинэ ажил авчрахын тулд ирсэн. Тэр Хуучин Гэрээг тайлбарлахаар, эсвэл Хуучин Гэрээний ажлыг баримтлахаар ирээгүй. Түүний ажил Хуулийн эрин үеийг үргэлжлүүлэн хөгжүүлэхийн төлөө байгаагүй, учир нь Түүний ажил Библийг сууриа болгосон эсэхийг огтхон ч авч үзээгүй; Есүс зүгээр л Өөрийн хийх учиртай ажлыг хийхээр ирсэн билээ. Тиймээс Тэр Хуучин Гэрээний зөгнөлүүдийг тайлбарлаагүй, мөн Хуучин Гэрээний Хуулийн эрин үеийн үгийн дагуу ч ажиллаагүй. Тэрээр Хуучин Гэрээнд хэлсэн зүйлийг үл ойшоож, энэ нь Түүний ажилтай санал нийлж байгаа эсэхэд анхаарал хандуулаагүй ба бусад хүмүүс Түүний ажлын талаар юу мэдэж байгааг, эсвэл үүнийг хэрхэн яллаж байгааг анхаараагүй. Хэдийгээр олон хүн Хуучин Гэрээний эш үзүүлэгчдийн зөгнөлийг ашиглан Түүнийг яллаж байсан ч Тэр зүгээр л хийх учиртай ажлаа хийсээр байсан юм. Хүмүүст Түүний ажил үндэс суурьгүй мэт харагдсан, мөн Хуучин Гэрээний тэмдэглэлүүдтэй тохирохгүй зүйл их байсан. Энэ нь хүний алдаа бус уу? Бурханы ажилд ёс заншлыг хэрэглэх хэрэгтэй гэж үү? Бурханы ажил эш үзүүлэгчдийн зөгнөлийн дагуу байх ёстой гэж үү? Эцсийн эцэст аль нь илүү агуу вэ: Бурхан уу, эсвэл Библи үү? Яагаад Бурхан Библийн дагуу ажиллах ёстой юм бэ? Бурхан Библиэс хэтрэн гарах эрхгүй юм гэж үү? Бурхан Библийг орхиж, өөр ажил хийж болохгүй гэж үү? Яагаад Есүс болон Түүний шавь нар Амралтын өдрийг сахиагүй вэ? Хэрвээ Есүс Амралтын өдрийг харгалзан үзэж, Хуучин Гэрээний тушаалуудын дагуу хэрэгжүүлэх байсан бол яагаад ирснийхээ дараа Амралтын өдрийг сахихын оронд хөл угааж, толгой бүтээж, талх хуваж, дарс уусан бэ? Энэ бүхэн нь Хуучин Гэрээний тушаалуудад байхгүй байгаа бус уу? Хэрвээ Есүс Хуучин Гэрээг мөрдсөн юм бол яагаад эдгээр ёс заншлыг зөрчсөн юм бэ? Бурхан, Библи хоёрын аль нь нэгдүгээрт байдгийг чи мэдэх ёстой! Амралтын өдрийн Эзэн болохоор Тэр бас Библийн Эзэн байж чадах бус уу?

Шинэ Гэрээний цаг үед Есүсийн хийсэн ажил шинэ ажлыг эхлүүлсэн юм: Тэр Хуучин Гэрээний ажлын дагуу ажиллаагүй, Хуучин Гэрээний Еховагийн хэлсэн үгийг ч мөрдөөгүй. Тэр Өөрийн ажлыг хийж, илүү шинэлэг ажил хийсэн бөгөөд тэрхүү ажил нь хуулиас дээгүүр байв. Тиймээс Тэр: “Хуулийг эсвэл эш үзүүлэгчдийг үгүй болгохын тулд Намайг ирсэн гэж бүү бод. Би үгүй болгохын тулд биш харин гүйцэлдүүлэхийн тулд ирсэн билээ” гэж хэлсэн. Тиймээс Түүний гүйцэлдүүлсэн зүйлсийн дагуу ихээхэн ёс заншил эвдэгдсэн. Амралтын өдөр Түүнийг шавь нараа дагуулан тариан талбайгаар явахад шавь нар нь тариан түрүү түүж, идсэн; Тэрээр Амралтын өдрийг сахиагүй бөгөөд “хүний Хүү Амралтын өдрийн ч Эзэн мөн” гэж хэлсэн билээ. Тухайн үед, израильчуудын дүрмийн дагуу Амралтын өдрийг сахиагүй хэн боловч чулуугаар цохиулж үхэх ёстой байсан юм. Гэвч Есүс ариун сүмд ч ороогүй, Амралтын өдрийг ч сахиагүй бөгөөд Түүний ажлыг Хуучин Гэрээний үед Ехова хийж байгаагүй. Тиймээс Есүсийн хийсэн ажил Хуучин Гэрээний хуулиас давсан, энэ нь үүнээс илүү өндөр байсан ба үүний дагуу байгаагүй. Нигүүлслийн эрин үед Есүс Хуучин Гэрээний хуулийн дагуу ажиллаагүй бөгөөд тэдгээр ёс заншлыг аль хэдийн зөрчсөн. Харин израильчууд Библитэй улайран зууралдаж, Есүсийг ялласан—энэ нь Есүсийн ажлыг үгүйсгэж байгаа хэрэг бус уу? Өнөөдөр шашны ертөнц ч бас Библитэй улайран зууралддаг ба “Библи бол ариун ном бөгөөд үүнийг унших ёстой” гэж зарим хүн хэлдэг. Зарим нь: “Бурханы ажлыг үүрд баримтлах ёстой, Хуучин Гэрээ бол израильчуудтай хийсэн Бурханы гэрээ, үүнээс салж болохгүй ба Амралтын өдрийг үргэлж сахих ёстой!” гэж хэлдэг. Тэд инээдтэй биш гэж үү? Яагаад Есүс Амралтын өдрийг сахиагүй вэ? Тэр нүгэл үйлдэж байсан уу? Хэн ийм зүйлийг нэгд нэггүй ойлгож чадах вэ? Хүмүүс Библийг хэрхэн унших нь хамаагүй, ойлгохуйн хүчээ ашиглан Бурханы ажлыг мэдэх боломжгүй. Тэд Бурханы талаарх цэвэр мэдлэгийг олж авч чадахгүйгээр үл барам, үзэл нь бүр илүү жигшмээр болж, улмаар Бурханыг эсэргүүцэж эхэлнэ. Хэрвээ бие махбодтой болсон өнөөдрийн Бурхан байгаагүй бол хүмүүс үзлийнхээ улмаас сүйрч, Бурханы гэсгээлт дунд үхэх байлаа.

БИБЛИЙН ТАЛААР 2

Библийг бас Хуучин ба Шинэ Гэрээ гэж нэрлэдэг. “Гэрээ” гэж юуг хэлдгийг та нар мэдэх үү? Хуучин Гэрээн дэх “гэрээ” нь, Ехова египетчүүдийг хөнөөж, израильчуудыг Фараоноос аврах үедээ Израилийн ард түмэнтэй хийсэн гэрээнээс гарч ирсэн. Мэдээж энэхүү гэрээний баталгаа нь тотгонд түрхсэн хурганы цус байв. Үүгээр дамжуулан Бурхан хүнтэй гэрээ байгуулсан ба үүнд, хаалганыхаа дээр болон хоёр хажуу талд хурганы цус түрхсэн хүмүүс нь бүгд израильчууд буюу Бурханы сонгосон хүмүүс бөгөөд бүгдийг нь Ехова өршөөнө гэж бичсэн байлаа (учир нь Ехова тэр үед Египетийн бүх ууган хөвгүүд болон хонь малын бүх ууган

төлийг хөнөөх гэж байсан юм). Энэ гэрээ нь хоёр түвшний утга учиртай. Египетийн ямар ч хүн, эсвэл малыг Ехова аврахгүй байх байсан; Тэрээр тэдний бүх ууган хөвгүүд болон ууган хонь малыг хөнөөх гэж байв. Тиймээс Еховагийн гэрээний үр дүнд египетчүүд хатуу чанд гэсгээгдэнэ гэж зөгнөлийн олон номд урьдчилан хэлсэн байлаа. Энэ бол гэрээний эхний түвшний утга учир юм. Ехова Египетийн ууган хөвгүүд болон бүх ууган төлийг алж, израильчуудыг бүгдийг нь өршөөсөн нь Израиль нутгийн бүх хүнийг Ехова нандигнан хайрлаж, бүгдийг нь өршөөх байсан гэх утгатай байсан юм; Тэр тэдэн дээр урт хугацааны ажил хийхийг хүсэж, хурганы цус ашиглан тэдэнтэй гэрээ байгуулжээ. Тэр үеэс эхлээд Ехова израильчуудыг хөнөөхгүй бөгөөд тэд үүрд Түүний сонгосон хүмүүс байх болно гэж хэлсэн юм. Израилийн арван хоёр овгийн дунд Тэр бүхий л Хуулийн эрин үеийн ажлаа эхлүүлж, Өөрийн бүх хуулийг израильчуудад илчилж, тэдний дундаас эш үзүүлэгчид, шүүгчдийг сонгох байсан ба тэд Түүний ажлын төвд байх байлаа. Эрин үе өөрчлөгдөхгүй л бол зөвхөн сонгогдсон хүмүүсийн дунд ажиллана гэсэн гэрээг Ехова тэдэнтэй байгуулжээ. Еховагийн гэрээ нь хувиршгүй байсан, учир нь энэ нь цусаар хийгдсэн бөгөөд Түүний сонгосон хүмүүстэй байгуулагдсан. Илүү чухал нь, Тэр тохиромжтой цар хүрээ болон байг сонгож, үүгээр дамжуулан бүх эрин үеийн төлөөх Өөрийн ажлаа эхлэх байсан тул хүмүүс гэрээг нэн чухал хэмээн үзсэн. Энэ бол гэрээний утга учрын хоёр дахь түвшин юм. Гэрээ байгуулагдахаас өмнө байсан Эхлэлийг оруулахгүй бол Хуучин Гэрээний бусад бүх ном нь гэрээ байгуулагдсаны дараах израильчуудын дундах Бурханы ажлыг тэмдэглэсэн байдаг. Мэдээж Харь үндэстнүүдийн талаарх бүртгэл хааяа байдаг боловч ерөнхийдөө Хуучин Гэрээ нь Израиль дахь Бурханы ажлыг баримтжуулдаг. Израильчуудтай байгуулсан Еховагийн гэрээний улмаас Хуулийн эрин үед бичигдсэн номуудыг Хуучин Гэрээ гэж нэрлэдэг. Тэдгээр нь израильчуудтай байгуулсан Еховагийн гэрээгээр нэрлэгдсэн.

Шинэ Гэрээ нь, Есүсийн загалмай дээр асгаруулсан цус болон Түүнд итгэсэн бүхэнтэй байгуулсан гэрээгээр нь нэрлэгдсэн. Есүсийн гэрээ ийм байв: Түүний урсгасан цусаар гэм нүглээ уучлуулахын тулд хүмүүс Түүнд итгэх ёстой байсан ба тэгснээр тэд аврагдаж, Түүгээр дамжуулан дахин төрж, нүгэлтнүүд байхаа болих байсан; хүмүүс Түүнд итгэж байж л Түүний нигүүлслийг хүлээн авах бөгөөд үхсэнийхээ дараа тамд зовохгүй байх байсан юм. Нигүүлслийн эрин үед бичигдсэн бүх ном энэ гэрээний дараа бий болсон бөгөөд тэдгээр нь бүгд энэ үед агуулагдсан ажил болон айлдварыг баримтжуулдаг. Тэдгээр нь Эзэн Есүсийн цовдлолын аврал, эсвэл гэрээнээс цааш хэтэрдэггүй; тэдгээр нь бүгд Эзэн доторх, туршлагатай ахан дүүсийн бичсэн ном. Тиймээс эдгээр ном ч бас гэрээний нэрээр нэрлэгдсэн: Тэдгээрийг Шинэ Гэрээ гэж нэрлэдэг. Энэ хоёр гэрээ нь зөвхөн Нигүүлслийн эрин үе болон Хуулийн эрин үеийг агуулдаг бөгөөд төгсгөлийн эрин үетэй ямар ч холбоогүй. Тиймээс Библи нь эцсийн өдрүүдийн өнөөгийн хүмүүст тийм ч их хэрэггүй. Энэ нь, хамгийн ихдээ л түр зуурын лавлагаа болж болох ч үндсэндээ хэрэглээний үнэ цэн тун багатай. Гэсэн ч шашны хүмүүс үүнийг ихэд

эрхэмлэсээр байдаг. Тэд Библийг мэддэггүй; зөвхөн Библийг яаж тайлбарлах тухай л мэддэг бөгөөд үүний эх сурвалжийн талаар үндсэндээ мэддэггүй. Библид хандах тэдний хандлага ийм байдаг: Библи дэх бүх зүйл зөв, ямар ч алдаа мадаг байхгүй. Библи бол зөв бөгөөд алдаагүй гэж эхлээд тодорхойлсон учраас тэд үүнийг асар их сонирхон судалж, шинжилдэг. Өнөөдрийн ажлын үе шатыг Библид зөгнөөгүй. Бүх газрын дундаас хамгийн харанхуйд нь явагдах байлдан дагуулалтын ажлын талаар хэзээ ч дурдаагүй, учир нь энэ нь хамгийн сүүлийн үеийн ажил билээ. Ажлын эрин үе өөр учраас, ажлын энэ үе шат эцсийн өдрүүдэд явагдана гэдгийг Есүс Өөрөө ч мэдэхгүй байсан, тэгвэл эцсийн өдрүүдийн хүмүүс Библийг судалснаар ажлын энэ үе шатыг Библиэс яаж олж чадах юм бэ?

Библийг тайлбарладаг ихэнх хүмүүс логик дүгнэлт хэрэглэдэг ба ямар ч бодит үндэслэл байдаггүй. Олон зүйлд дүгнэлт хийхийн тулд тэд ердөө логик ашигладаг. Жилээс жилд хэн ч Библийг задлан шинжилж зүрхлээгүй, эсвэл Библид “үгүй” гэж хэлж чадаагүй, учир нь энэ ном бол “ариун ном” бөгөөд хүмүүс үүнийг Бурхан шиг шүтдэг. Энэ нь хэдэн мянган жилийн туршид үргэлжилсэн. Бурхан ямар ч анхаарал хандуулаагүй бөгөөд Библийн дотоод түүхийг хэн ч нээж илрүүлээгүй. Библийг эрхэмлэх нь шүтээн шүтэж байгаа хэрэг гэж бид хэлдэг ч тэрхүү үнэнч итгэгчдийн хэн ч үүнийг ингэж харж зүрхэлдэггүй бөгөөд тэд чамд: “Ах минь! Тэгж бүү хэл, тэр чинь аймшигтай! Бурханыг доромжилж чи яаж чадаж байна аа?” гэж хэлнэ. Дараа нь тэд зовсон царай гарган: “Өө өршөөлт Есүс, авралын Эзэн минь, түүний нүглийг уучлахыг би Танаас гуйя, учир нь Та бол хүнийг хайрладаг Эзэн билээ, бид бүгд нүгэлтэй, бидэнд агуу энэрлээ үзүүлээч, амен” гэх болно. Тэд ийм л “сүсэгтэй”; тэдний хувьд үнэнийг хүлээн зөвшөөрөх нь яаж амархан байж чадах юм бэ? Чиний хэлсэн үг тэднийг цочтол айлгана. Библийг хүний санаа бодол, хүний үзлээр сэвтүүлж болно гэж хэн ч бодож зүрхлэхгүй ба хэн ч энэ өө сэвийг харж чадахгүй. Библид байгаа зүйлсийн зарим нь хувь хүний туршлага болон мэдлэг, зарим нь Ариун Сүнсний гэгээрэл бөгөөд хүний оюун ухаан болон бодлын хольц ч бас бий. Бурхан эдгээр зүйлд хэзээ ч хөндлөнгөөс оролцоогүй боловч үүнд хязгаар байдаг: Эдгээр зүйл хэвийн хүний бодлоос хэтэрч чадахгүй, хэрвээ хэтэрвэл Бурханы ажилд хөндлөнгөөс оролцож, саад болж байгаа хэрэг. Хэвийн хүний бодлоос давдаг зүйлс нь Сатаны ажил юм, учир нь энэ нь хүмүүсийг үүргээс нь салгадаг, энэ бол Сатаны ажил, Сатанаар чиглүүлэгддэг учраас энэ мөчид Ариун Сүнс тэгж авирлахыг чинь зөвшөөрөхгүй. Заримдаа зарим ах эгч нар: “Би ийм, ийм маягаар ажиллавал зүгээр үү?” гэж асуудаг. Би тэдний биеийн хэмжээг хараад, “Зүгээр!” гэж хэлдэг. Бас “Хэрвээ би ийм ийм маягаар ажиллавал миний байр байдал хэвийн үү?” гэдэг зарим хүн ч байдаг. Тэгэхэд нь Би: “Тийм ээ! Хэвийн, тун хэвийн!” гэж хэлдэг. Бусад нь: “Миний хувьд ийм маягаар ажиллах нь зүгээр үү?” гэж асуудаг. Би тэдэнд “Үгүй!” гэдэг. Тэд: “Энэ нь түүний хувьд зүгээр мөртөө яагаад миний хувьд тийм биш гэж?” гэцгээдэг. Тэгэхэд Би: “Чиний хийж байгаа зүйл Сатанаас үүдэлтэй, үймээн самуун бөгөөд сэдлийн чинь эх сурвалж бурууддаг” гэж хэлдэг.

Бас ажил хангалттай явагдаагүй үе ч байсан ба ах эгч нар үүнийг мэддэггүй байсан. Зарим хүн Надаас тодорхой байдлаар ажиллах нь зүгээр үү гэж асуудаг бөгөөд тэдний үйлдэл ирээдүйн ажилд саад болохгүй гэдгийг харах үедээ Би зүгээр ээ гэж хэлдэг. Ариун Сүнсний ажил хүмүүст цар хүрээ өгдөг; хүмүүс Ариун Сүнсний хүслийг яг таг дагах хэрэггүй, учир нь хүмүүс хэвийн бодол, сул талтай байдаг бөгөөд тэдэнд махан биеийн зарим нэг хэрэгцээ, бодитой асуудлууд байдаг ба үндсэндээ өөрсдөө хянах ямар ч аргагүй бодол санаа уураг тархинд нь байдаг. Хүмүүсээс шаарддаг бүхэнд минь хязгаар бий. Зарим хүн, Миний үг хоёрдмол утгатай ба аль нэгээр нь хий хэмээн хэлж байна гэж итгэдэг—яагаад гэвэл, Миний шаардлагад тохирсон цар хүрээ байдгийг чи ойлгодоггүй. Хэрвээ энэ нь чиний төсөөлдөг шиг байсан бол, хэрвээ Би бүх хүнийг ялгахгүйгээр ижил шаардлага тавьж, бүгдээс нь адилхан биеийн хэмжээнд хүрэхийг шаардсан бол энэ нь бүтэхгүй. Энэ нь боломжгүй зүйлийг гуйж байгаа хэрэг бөгөөд энэ нь Бурханы ажлын зарчим биш, хүний ажлын зарчим билээ. Бурханы ажил хүмүүсийн бодит нөхцөл байдлын дагуу хэрэгжиж, төрөлхийн хэв чанарт нь үндэслэдэг. Энэ нь бас сайн мэдээ түгээх зарчим юм: Чи аажмаар хийж, энэ бүхнийг зөнгөөр нь явуулах хэрэгтэй; үнэнийг хэн нэгэнд тодорхой ярих үед чинь л тэд ойлгоно, тэр үед л тэд Библийг хойш тавьж чадна. Хэрвээ Бурхан ажлын энэ үе шатыг хийгээгүй бол тогтсон заншлыг хэн эвдэж чадах юм бэ? Хэн шинэ ажил хийж чадах вэ? Библийн гаднах шинэ замыг хэн олж чадах вэ? Хүмүүсийн уламжлалт үзэл болон феодалын ёс зүй маш цадигаа алдсан учраас тэд өөрсдөө эдгээр зүйлийг хаях чадваргүй, ингэж хийх эр зориг ч тэдэнд байхгүй. Өнөөдрийн хүмүүс, зүрх сэтгэлийг нь эзэмдсэн үг буюу Библи дэх хэдхэн үхмэл үгэнд баригдсан талаар хэлэхийн ч хэрэггүй. Тэд яаж Библийг хаяхыг хүсэх юм бэ? Библийн гаднах замыг тэд яаж амархан хүлээн зөвшөөрч чадах юм бэ? Чи Библийн дотоод түүх болон Ариун Сүнсний ажлын зарчмуудыг тодорхой ярихгүй л бол болохгүй, ингэснээр бүх хүн бүрэн итгэх ба энэ нь туйлын шаардлагатай. Учир нь, шашин доторх хүн бүр Библийг өргөмжилж, Бурхан шиг шүтдэг, мөн Бурханыг Библиэр хязгаарлахаар оролддог бөгөөд тэр ч бүү хэл Бурханыг дахин нэг удаа загалмайд цовдолмогцоо л зорилгодоо хүрдэг.

БИБЛИЙН ТАЛААР 3

Библид байгаа бүхэн нь Бурханы биечлэн хэлсэн үгийн тэмдэглэл биш. Библи нь зүгээр л Бурханы ажлын өмнөх хоёр үе шатыг баримтжуулдаг бөгөөд үүний нэг хэсэг нь эш үзүүлэгчдийн зөгнөлүүдийн тэмдэглэл, нөгөө хэсэг нь эрин үеүдийн туршид Бурханы ашиглаж байсан хүмүүсийн бичсэн туршлага, мэдлэг юм. Хүний туршлагад хүний санаа бодол, мэдлэг холилддог ба үүнээс зайлсхийх аргагүй. Библийн олон номд хүний үзэл, хүний өрөөсгөл хандлага, утгагүй ойлголт байдаг.

Мэдээж үгийн ихэнх нь Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийн үр дүн бөгөөд тэдгээр нь зөв ойлголт юм—гэхдээ тэдгээрийг үнэний зөв зүйтэй илэрхийлэл гэж хэлж болохгүй. Зарим зүйлийн талаарх тэдний үзэл бодол нь хувийн туршлагаас гарсан мэдлэг, эсвэл Ариун Сүнсний гэгээрлээс цаашгүй. Эш үзүүлэгчдийн зөгнөлийг Бурхан биечлэн зааварчилсан: Исаиа, Даниел, Езра, Иеремиа, Езекиел гэх мэт хүмүүсийн зөгнөлүүд нь Ариун Сүнсний шууд зааврaас ирсэн, энэ хүмүүс зөнчид байсан ба зөгнөлийн Сүнсийг хүлээн авсан, мөн бүгд Хуучин Гэрээний эш үзүүлэгчид байсан юм. Хуулийн эрин үед, Еховагийн онгодыг хүртсэн энэ хүмүүс олон зөгнөл хэлж, үүнийг нь Ехова шууд зааварчилж байв. Яагаад Ехова тэдэн дээр ажилласан бэ? Израилийн ард түмэн нь Бурханы сонгосон хүмүүс байсан учраас эш үзүүлэгчдийн ажил тэдний дунд хийгдэх ёстой байсан; тийм учраас эш үзүүлэгчид ийм илчлэл хүлээн авч чаддаг байлаа. Үнэндээ, өөрсдөд нь өгсөн Бурханы илчлэлийг тэд өөрсдөө ч ойлгоогүй. Тэдний амаар дамжуулан Ариун Сүнс тэдгээр үгийг хэлсэн болохоор хожмын хүмүүс тэдгээр зүйлийг ойлгож, энэ нь үнэхээр Бурханы Сүнсний, Ариун Сүнсний ажил бөгөөд хүнээс ирээгүй гэдгийг нь харж, Ариун Сүнсний ажлын баталгааг тэдэнд өгөх байсан юм. Нигүүлслийн эрин үед Есүс Өөрөө энэ бүх ажлыг тэдний оронд хийсэн тул хүмүүс дахин зөгнөл хэлээгүй. Тэгвэл Есүс эш үзүүлэгч байсан уу? Есүс мэдээж эш үзүүлэгч байсан, гэхдээ Тэр бас элчүүдийн ажлыг ч хийж чаддаг байсан—Тэрээр газар нутаг даяар зөгнөл хэлж, тунхаглаж, хүмүүст зааж сургахын аль алийг чаддаг байв. Гэсэн ч Түүний хийсэн ажил болон төлөөлж байсан ялгамж чанар нь адилхан байгаагүй. Тэр бүх хүн төрөлхтнийг золин аварч, хүнийг нүглээс золин аврахаар ирсэн; Тэр эш үзүүлэгч, элч байсан боловч түүнээс ч илүүгээр Тэр бол Христ байсан. Эш үзүүлэгч зөгнөл хэлж болох боловч тийм эш үзүүлэгчийг Христ гэж хэлж болохгүй. Тухайн үед Есүс маш их зөгнөл хэлсэн тул Түүнийг эш үзүүлэгч гэж хэлж болно, гэхдээ Тэр эш үзүүлэгч тул Христ биш гэж болохгүй. Яагаад гэвэл, ажлын нэг үе шатыг биелүүлэхдээ Тэрээр Бурханыг Өөрийг нь төлөөлж байсан бөгөөд ялгамж чанар нь Исаиагийнхаас өөр байсан: Тэр золин авралын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд ирж, бас хүний амийг хангасан бөгөөд Бурханы Сүнс Түүнд шууд ирсэн. Түүний хийсэн ажилд Бурханы Сүнсний онгод юм уу Еховагийн заавар байгаагүй. Харин ч Сүнс шууд ажилласан ба Есүс эш үзүүлэгчтэй адил байгаагүйг батлахад энэ нь хангалттай. Түүний хийсэн ажил нь золин авралын ажил байсан бөгөөд зөгнөл хэлэх нь үүний дараагийн зүйл юм. Тэр эш үзүүлэгч, элч байсан, гэхдээ түүнээс ч илүүтэйгээр Золин аврагч байсан билээ. Харин зөнчид зөвхөн зөгнөл хэлж л чаддаг ба өөр ажил хийхэд Бурханы Сүнсийг төлөөлж чаддаггүй байв. Өмнө нь хүний хэзээ ч хийж байгаагүй ихээхэн ажлыг Есүс хийж, хүн төрөлхтнийг золин аврах ажлыг хийсэн учраас Исаиа мэтийн хүмүүсээс өөр байлаа. Энэ нь зарим хүнд саад учруулдаг учраас тэд өнөөдрийн урсгалыг хүлээн зөвшөөрдөггүй. Тэд: “Хуучин Гэрээнд бас олон эш үзүүлэгч олон үг хэлсэн, тэгвэл тэд яагаад бие махбод болсон Бурхан байгаагүй юм бэ? Өнөөдрийн Бурхан үг хэлдэг, гэхдээ Тэр

бол бие махбодтой болсон Бурхан гэдгийг батлахад энэ хангалттай гэж үү? Чи Библийг өргөмжилдөг ч үгүй, судалдаг ч үгүй, тэгвэл юунд үндэслэж Тэр бол бие махбод болсон Бурхан гэж хэлж байгаа юм бэ? Тэдэнд Ариун Сүнс зааварчилсан гэж чи хэлдэг бөгөөд ажлын энэ үе шат бол Бурханы биечлэн хийсэн ажил гэж итгэдэг, тэгвэл ингэж үзэх үндэслэл чинь юу вэ? Чи өнөөдрийн Бурханы үгэнд анхаарлаа төвлөрүүлэн, Библийг үгүйсгэж, хойш тавьсан мэт харагддаг" гэцгээдэг. Иймээс тэд чамайг тэрс үзэл, буруу номд итгэдэг гэдэг.

Хэрвээ чи эцсийн өдрүүдэд Бурханы ажлыг гэрчлэхийг хүсвэл Библийн дотоод түүх, Библийн бүтэц болон Библийн мөн чанарыг ойлгох ёстой. Өнөөдөр, Библи бол Бурхан, Бурхан бол Библи гэж хүмүүс итгэдэг. Иймээс ч тэд Библийн бүх үг бол зөвхөн Бурханы хэлсэн үг бөгөөд тэдгээрийг бүгдийг нь Бурхан хэлсэн гэж итгэдэг. Хэдийгээр Хуучин болон Шинэ Гэрээний жаран зургаан номыг бүгдийг нь хүмүүс бичсэн боловч тэдгээрт бүгдэд нь Бурханы онгод өгөгдсөн бөгөөд Ариун Сүнсний айлдварын тэмдэглэл байсан гэж ч Бурханд итгэдэг хүмүүс боддог. Энэ нь хүний эндүү ташаа ойлголт бөгөөд баримтуудтай огтхон ч нийцдэггүй. Үнэндээ зөгнөлийн номноос гадна, Хуучин Гэрээний ихэнх нь түүхэн тэмдэглэл юм. Шинэ Гэрээний зарим захидал хүмүүсийн туршлагаас бий болсон, зарим нь Ариун Сүнсний гэгээрлээс гарсан; жишээлбэл, Паулын захидлууд хүний ажлаас үүсэн гарсан, тэдгээр нь бүгд Ариун Сүнсний гэгээрлийн үр дүн байсан бөгөөд чуулгануудын төлөө бичигдсэн, чуулганы ах эгч нарт зориулсан сургамж, зоригжуулалтын үгс байсан юм. Тэдгээр нь Ариун Сүнсний хэлсэн үг биш—Паул Ариун Сүнсний өмнөөс ярьж чадахгүй, тэрээр эш үзүүлэгч ч байгаагүй, тэр ч бүү хэл, Иоханы харсан үзэгдлийг хараагүй. Түүний захидлууд Ефес, Коринт, Галатын чуулганууд болон бусад чуулганд зориулан бичигдсэн. Тиймээс Шинэ Гэрээний Паулын захидлууд нь чуулгануудад зориулж бичсэн Паулын захидлууд байсан бөгөөд Ариун Сүнсний онгод биш, мөн Ариун Сүнсний шууд айлдвар ч биш байсан. Тэдгээр нь ердөө л ажлынхаа явцад чуулгануудад бичсэн Паулын сургамж, тайтгаруулалт, зоригжуулалтын үгс байв. Иймээс тэдгээр нь ч бас тухайн үеийн Паулын ихэнх ажлын тэмдэглэл юм. Тэдгээрийг Эзэн доторх бүх ах эгч нарт зориулж бичсэн, ингэснээр тухайн үеийн чуулгануудын ах эгч нар түүний зөвлөгөөг дагаж, Эзэн Есүсийн гэмшлийн замыг даган мөрдөх байлаа. Тухайн үеийн, эсвэл хожмын чуулганууд бүгд өөрийнх нь бичсэн зүйлийг идэж уух ёстой гэж Паул яавч хэлээгүй, мөн түүний үг бүгд Бурханаас ирсэн гэж ч хэлээгүй. Тэр үеийн чуулганы нөхцөл байдлын дагуу тэрээр зүгээр л ах эгч нартай ярилцаж, тэдэнд сургамжилж, итгэлийг нь зоригжуулсан бөгөөд зүгээр л хүмүүст номлож, эсвэл сануулж, сургамжилжээ. Түүний үг өөрийнх нь ачаанд үндэслэсэн бөгөөд эдгээр үгээр дамжуулан хүмүүст тусалж дэмжсэн. Тэрээр тухайн үеийн чуулгануудын элчийн ажлыг хийсэн, Эзэн Есүсийн ашигладаг ажилчин байсан тул чуулгануудын төлөө хариуцлага үүрч, чуулгануудын ажлыг өөртөө авч, ах эгч нарын байдлыг мэдэж авах ёстой байсан—үүнээс болж тэрээр Эзэн доторх бүх ах эгч нарт захидал

бичжээ. Түүний хэлсэн, хүмүүсийг босгон байгуулж, тэдэнд эерэг нөлөө үзүүлсэн бүхэн нь зөв байсан боловч энэ нь Ариун Сүнсний айлдварыг төлөөлөөгүй ба энэ нь Бурханыг төлөөлж чадахгүй. Хүмүүс хүний туршлагын тэмдэглэл болон хүний захидлуудыг чуулгануудад хандсан Ариун Сүнсний үг гэж үзэх нь эндүү ташаа ойлголт бөгөөд үлэмж их доромжлол юм! Ялангуяа чуулгануудад бичсэн Паулын захидлын тухайд ийм байдаг, учир нь түүний захидлууд тухайн үеийн чуулган бүрийн нөхцөл байдал, төлөв байдалд үндэслэн, ах эгч нарт зориулан бичигдсэн бөгөөд Эзэн дотор ах эгч нарт сургамжлахын төлөө байсан, ингэснээр тэд Эзэн Есүсийн нигүүлслийг хүртэж чадах байлаа. Түүний захидлууд тухайн үеийн ах эгч нарыг сэргээхийн төлөө байсан. Энэ нь түүний өөрийн ачаа байсан бөгөөд түүнд Ариун Сүнсний өгсөн ачаа байсан гэж хэлж болно; эцсийн эцэст тэр бол тухайн үеийн чуулганууды залж чиглүүлж, чуулгануудад захидал бичиж, тэдэнд сургамжилж байсан элч юм, энэ нь түүний үүрэг хариуцлага байлаа. Түүний ялгамж чанар ердөө ажлаа хийж буй элчийнх байсан бөгөөд тэр бол ердөө Бурханы илгээсэн элч байсан юм; тэр эш үзүүлэгч, эсвэл зөнч байгаагүй. Түүний хувьд өөрийнх нь ажил болон ах эгч нарын амь хамгийн чухал байв. Тиймээс тэр Ариун Сүнсний өмнөөс ярьж чадаагүй. Түүний үг Ариун Сүнсний үг байгаагүй, тэр ч бүү хэл тэдгээрийг Бурханы үг гэж хэлж болохгүй, учир нь Паул Бурханы бүтээлээс цаашгүй бөгөөд мэдээж бие махбодтой болсон Бурхан биш байсан. Түүний ялгамж чанар Есүсийнхтэй адил байгаагүй. Есүсийн үг нь Ариун Сүнсний үг байсан, мөн Бурханы үг байсан, учир нь Түүний ялгамж чанар Христийнх, Бурханы Хүүгийнх байсан юм. Паул яаж Түүнтэй адил байж чадах юм бэ? Хэрвээ хүмүүс, Паулынх шиг захидал юм уу үгийг Ариун Сүнсний айлдвар хэмээн үзэж, Бурхан мэт шүтвэл, тэднийг огт ялган салгах чадваргүй гэж хэлж болно. Хатуухан хэлэх юм бол, энэ нь зүгээр л доромжлол биш гэж үү? Хүн яаж Бурханы өмнөөс ярьж чадах юм бэ? Хүмүүс түүний захидлууд болон түүний хэлсэн үгийн тэмдэглэлд мэхийж, тэдгээрийг ариун ном, эсвэл тэнгэрлэг ном шиг үзэж яаж болох юм бэ? Бурханы үгийг хүн санаандгүй хэлж болох уу? Хүн яаж Бурханы өмнөөс ярьж чадах юм бэ? Иймээс чуулгануудад бичсэн захидлуудад нь түүний өөрийн санаа бодол холилдоогүй гэж чи яаж хэлж болох юм бэ? Тэдгээрт яаж хүний санаа бодол холилдоогүй байх юм бэ? Тэрээр хувийн туршлага болон өөрийнхөө мэдлэгт үндэслэн чуулгануудад захидал бичсэн. Тухайлбал, тодорхой нэг санал агуулсан захидлыг Паул Галатын чуулгануудад бичсэн ба Петр өөр өнцгөөс өөр захиа бичсэн. Аль нь Ариун Сүнснээс ирсэн бэ? Хэн ч итгэлтэй хэлж чадахгүй. Тиймээс тэд хоёулаа чуулгануудын төлөө ачаа үүрсэн гэж хэлж болно, гэхдээ тэдний захиа биеийн хэмжээг нь төлөөлдөг, мөн ах эгч нарын төлөө гэсэн тэдний хангалт, дэмжлэг болон чуулганы төлөөх тэдний ачааг төлөөлдөг, тэдгээр нь зөвхөн хүний ажлыг л төлөөлдөг; тэдгээр нь тэр чигтээ Ариун Сүнснийх байгаагүй. Хэрвээ түүний захидлуудыг Ариун Сүнсний үг гэх юм бол чи мунхаг бөгөөд доромжлол үйлдэж байна! Паулын захидлууд болон Шинэ Гэрээний бусад захидал нь орчин үеийн

сүнслэг хүмүүсийн дурсамжтай адилхан: Тэдгээр нь Вотчман Нигийн ном, эсвэл Лауренсийн туршлага гэх мэттэй адилхан. Ердөө л орчин үеийн сүнслэг хүмүүсийн ном Шинэ Гэрээнд эмхэтгэгдээгүй, харин энэ хүмүүсийн мөн чанар адилхан: Тэд бол тодорхой хугацаанд Ариун Сүнсний ашиглаж байсан хүмүүс бөгөөд Бурханыг шууд төлөөлж чадаагүй.

Шинэ Гэрээний Матайн Сайн Мэдээ нь Есүсийн угийн бичгийг тэмдэглэсэн байдаг. Эхэндээ энэ нь Есүс бол Абрахам болон Давидын удам, Иосефийн хүү байсан гэдэг; дараа нь Есүс Ариун Сүнснээс олдсон бөгөөд онгон эмэгтэйгээс төрсөн гэж байдаг, энэ нь, Тэр бол Иосефийн хүү ч биш, эсвэл Абрахам, Давид хоёрын үр удам ч биш байсан гэсэн үг юм. Гэхдээ угийн бичигт Есүсийг Иосефтэй холбохоор зүтгэдэг. Дараа нь, угийн бичигт Есүсийн төрсөн үйл явцыг тэмдэглэж эхэлдэг. Есүс Ариун Сүнснээс олдож, онгон эмэгтэйгээс төрсөн, Иосефийн хүү биш гэж хэлсэн байдаг. Гэсэн ч Есүс бол Иосефийн хүү байсан гэж угийн бичигт тодорхой бичсэн бөгөөд угийн бичгийг Есүст зориулж бичсэн учраас дөчин хоёр үе удмыг нь бичсэн. Иосефийн үед очиход Иосеф бол Мариагийн нөхөр байсан гэж зэрвэс хэлдэг бөгөөд энэ нь Есүс бол Абрахамын удам гэдгийг батлахын тулд хэлсэн үг юм. Энэ нь зөрчилдөөн бус уу? Угийн бичигт Иосефийн өвөг дээдсийг тодорхой баримтжуулсан байдаг, энэ нь илт Иосефийн угийн бичиг боловч Есүсийн угийн бичиг гэж Матай зүтгэдэг. Энэ нь Есүс Ариун Сүнснээс олдсон гэдэг баримтыг үгүйсгэдэг бус уу? Тиймээс Матайн бичсэн угийн бичиг нь хүний санаа биш үү? Утгагүй юм! Ийнхүү чи энэ ном нь тэр чигтээ Ариун Сүнснээс ирээгүй гэдгийг мэдэж болно. Бурхан газар дээр угийн бичигтэй байх ёстой гэж боддог зарим хүн байж магадгүй бөгөөд үүний үр дүнд тэд Есүсийг Абрахамын дөчин хоёр дахь удам болгосон. Энэ нь үнэхээр утгагүй! Газар дээр ирсний дараа Бурхан яаж угийн бичигтэй байх юм бэ? Хэрвээ чи Бурханд угийн бичиг байдаг гэвэл Түүнийг Бурханы бүтээлүүдийн дунд эрэмбэлж байгаа бус уу? Учир нь Бурхан бол газар дэлхийнх биш, харин бүтээлийн Эзэн бөгөөд махбодтой хэдий ч хүнтэй адил гол чанартай биш. Чи Бурханыг, Бурханы бүтээлтэй адил төрөл зүйл болгон тооцож яаж чадаж байна вэ? Абрахам Бурханыг төлөөлж чадахгүй; тэрээр тухайн үеийн Еховагийн ажлын бай байсан, мөн ердөө л Еховагийн сайшаасан итгэлт зарц байсан бөгөөд Израилийн ард түмний нэг байсан. Тэр яаж Есүсийн өвөг дээдэс байж чадах юм бэ?

Есүсийн угийн бичгийг хэн бичсэн бэ? Есүс Өөрөө бичсэн үү? Есүс тэдэнд “Миний угийн бичгийг бич” гэж биечлэн хэлсэн үү? Есүсийг загалмайд цовдлогдсоны дараа Матай үүнийг тэмдэглэсэн юм. Тухайн үед шавь нарт нь ойлгомжгүй байсан олон ажлыг Есүс хийгээд, ямар ч тайлбар хийгээгүй. Түүнийг явсны дараа шавь нар нь хаа сайгүй номлож, ажиллаж эхэлсэн бөгөөд ажлын тэрхүү үе шатны төлөө захидал болон сайн мэдээний номууд бичиж эхэлжээ. Шинэ Гэрээний сайн мэдээний номууд нь Есүсийг цовдлогдоноос хориос гучин жилийн дараа бичигдсэн юм. Урьд нь, Израилийн ард түмэн Хуучин Гэрээг л уншдаг байв. Өөрөөр

хэлбэл, Нигүүлслийн эрин үеийн эхэнд хүмүүс Хуучин Гэрээг уншдаг байлаа. Шинэ Гэрээ нь Нигүүлслийн эрин үед л гарч ирсэн юм. Есүсийг ажиллаж байх үед Шинэ Гэрээ байгаагүй; Түүнийг дахин амилж, тэнгэр өөд гарсны дараа хүмүүс Түүний ажлыг бичиж тэмдэглэсэн. Тэр үед л Дөрвөн Сайн Мэдээ гарч ирсэн, дээр нь нэмээд Паул, Петр хоёрын захидлууд, түүнчлэн Илчлэлийн Ном байсан. Есүсийг тэнгэр өөд гарснаас хойш гурван зуу гаруй жилийн дараа, дараагийн үеийнхэн эдгээр бичиг баримтыг сонгож цэгцэлсэн бөгөөд тэр үед л Библийн Шинэ Гэрээ бий болсон билээ. Энэ ажил дууссаны дараа л Шинэ Гэрээ бий болсон; энэ нь өмнө нь байгаагүй юм. Бурхан тэр бүх ажлыг хийж, Паул болон бусад элч нар янз бүрийн газрууд дахь чуулгануудад маш олон захидал бичсэн. Тэдний дараагийн хүмүүс захидлуудыг нь нэгтгэж, Патм арал дээр Иоханы тэмдэглэсэн хамгийн агуу үзэгдлийг хавсаргасан бөгөөд үүнд Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг зөгнөсөн байдаг. Хүмүүс ийм дарааллыг бий болгосон нь өнөөдрийн айлдваруудаас өөр юм. Өнөөдөр бичиж тэмдэглэдэг зүйл Бурханы ажлын алхмуудын дагуу байдаг; өнөөдөр хүмүүсийн оролцдог зүйл нь Бурханы биечлэн хийсэн ажил, биечлэн айлдсан үг юм. Чи—хүн төрөлхтөн—хөндлөнгөөс оролцох хэрэггүй; Сүнснээс шууд ирдэг үг нь алхам алхмаар зохицуулагддаг бөгөөд хүний тэмдэглэлийг зохицуулахаас өөр. Тэдний бичсэн зүйл боловсрол болон хэв чанарынх нь түвшний дагуу байсан гэж хэлж болно. Тэдний бичиж тэмдэглэсэн зүйл хүмүүсийн туршлага байсан бөгөөд тус бүрдээ өөрсдийн гэсэн бичих, мэдэх арга барилтай байсан бөгөөд тэмдэглэл бүхэн өөр байв. Тиймээс хэрвээ чи Библийг Бурхан шиг шүтдэг бол хэтэрхий мэдлэггүй, тэнэг юм! Яагаад чи өнөөдрийн Бурханы ажлыг эрж хайдаггүй вэ? Бурханы ажил л хүнийг аварч чадна. Библи хүнийг аварч чадахгүй, хүмүүс үүнийг хэдэн мянган жилийн турш уншлаа гээд өчүүхэн төдий ч өөрчлөлт гарахгүй бөгөөд хэрвээ Библийг шүтвэл чи хэзээ ч Ариун Сүнсний ажлыг олж авахгүй. Израиль дахь Бурханы ажлын хоёр үе шат хоёулаа Библид тэмдэглэгдсэн, иймээс эдгээр тэмдэглэлийн доторх бүх нэр Израилийнх, бүх хэрэг явдал Израилийнх байдаг; “Есүс” гэдэг нэр ч израиль хүний нэр юм. Хэрвээ чи өнөөдөр Библи уншсаар байвал тогтсон ёс заншилд баригдахгүй гэж үү? Библийн Шинэ Гэрээнд бичигдсэн зүйл нь Иудейн хэрэг явдал юм. Эх бичвэр нь Грек болон Еврей хэлний аль алин дээр байсан бөгөөд тухайн үед Түүнийг нэрлэж байсан нэр болон Есүсийн үг бүгд хүний хэлэнд харьяалагддаг. Загалмайд цовдлогдох үедээ Есүс: “Ели, Ели, лема сабахтани?” гэж хэлсэн. Энэ нь Еврей хэл биш гэж үү? Есүс Иудейд бие махбодтой болсон учраас л энэ бөгөөд Бурхан бол Иудей гэдгийг баталдаггүй. Өнөөдөр Бурхан Хятадад махбод болсон тул Түүний хэлдэг бүхэн гарцаагүй Хятад хэл дээр байдаг. Гэсэн ч үүнийг Библиэс орчуулсан Хятад хэлтэй харьцуулж болохгүй, учир нь эдгээр үгийн эх сурвалж өөр: Нэг нь хүмүүсийн бичсэн Еврей хэлээс үүддэг, нөгөө нь Сүнсний шууд айлдваруудаас үүдэн гардаг. Яаж ямар ч ялгаагүй байх юм бэ?

БИБЛИЙН ТАЛААР 4

Библийг ойлгож, тайлж чадна гэдэг үнэн замыг олохтой адил гэж олон хүн үздэг ч үнэн хэрэгтээ юмс үнэхээр ийм энгийн гэж үү? Библийн бодит байдлыг хэн ч мэдэхгүй: энэ нь Бурханы ажлын түүхэн тэмдэглэл, Бурханы ажлын өмнөх хоёр үе шатны гэрчлэлээс цаашгүй бөгөөд Бурханы ажлын зорилгын талаарх ямар ч ойлголтыг чамд өгдөггүй. Энэ нь, Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үе дэх Бурханы ажлын хоёр үе шатыг тэмдэглэсэн гэдгийг Библи уншсан хүн бүр мэднэ. Хуучин Гэрээ нь Израилийн түүх болон бүтээлийн цаг үеэс эхлээд Хуулийн эрин үеийн төгсгөл хүртэлх Еховагийн ажлыг тэмдэглэсэн байдаг. Шинэ Гэрээ нь Дөрвөн Сайн Мэдээнд байдаг газар дээрх Есүсийн ажил, түүнчлэн Паулын ажлыг бичсэн байдаг—эдгээр нь түүхэн тэмдэглэл бус уу? Өнгөрсөн үеийн зүйлс өнөөдөр түүх болдог, тэдгээр нь хэчнээн жинхэнэ, бодитой байх нь хамаагүй, түүх хэвээр бөгөөд түүх нь өнөөдөрт чиглэж чадахгүй, учир нь Бурхан түүхийг эргэн хардаггүй! Иймээс хэрвээ чи зөвхөн Библийг ойлгож, өнөөдөр Бурханы хийхээр зорьдог ажлын юуг ч ойлгодоггүй бол, мөн Бурханд итгэдэг ч Ариун Сүнсний ажлыг эрж хайдаггүй бол Бурханыг эрж хайна гэдэг юу гэсэн утгатайг ойлгодоггүй юм байна. Хэрвээ чи Израилийн түүхийг судлахын тулд, Бурхан бүх тэнгэр газрыг бүтээсэн тухай түүхийг шинжлэхийн тулд Библи уншдаг бол Бурханд итгэдэггүй юм байна. Гэвч өнөөдөр чи Бурханд итгэж, амийг эрэлхийлж, Бурханыг мэдэхээр эрэлхийлдэг, харин үхмэл бичиг үсэг, хоосон сургаал, эсвэл түүхийг ойлгохоор эрэлхийлдэггүй юм бол өнөөдрийн Бурханы хүслийг эрж хайж, Ариун Сүнсний ажлын чиглэлийг хайх ёстой. Хэрвээ чи археологич байсан бол Библийг уншиж болох юм—гэтэл тийм биш, харин Бурханд итгэдэг хүмүүсийн нэг бөгөөд өнөөдрийн Бурханы хүслийг эрж хайсан чинь дээр. Библийг уншаад хамгийн ихдээ л чи Израилийн түүхийн багахныг ойлгож, Абрахам, Давид болон Мосегийн амьдралын талаар мэдэж авч, тэд Еховаг хэрхэн хүндэлж байсныг, Өөрийг нь эсэргүүцсэн хүмүүсийг Ехова хэрхэн шатаасныг болон тухайн үеийн хүмүүстэй хэрхэн ярьж байсныг олж мэднэ. Чи өнгөрсөн үе дэх Бурханы ажлын талаар л олж мэднэ. Библийн тэмдэглэлүүд нь эртний Израилийн хүмүүс хэрхэн Бурханыг хүндэлж, Еховагийн удирдамж дор амьдарч байсантай холбоотой. Израильчууд Бурханы сонгосон хүмүүс байсан учраас, Хуучин Гэрээнээс чи Израилийн бүх ард түмэн Еховад үнэнч байсныг, Еховаг дуулгавартай дагаж байсан хүмүүс Түүгээр хэрхэн халамжлуулж, ерөөгдөж байсныг харж чадна; Бурхан Израильд ажиллах үедээ өршөөл, хайраар дүүрэн байсан, түүнчлэн бүхнийг залгигч галыг эзэмшиж байсан бөгөөд израильчууд бүгд ядуу дордоосоо эхлээд хүчтэйгээ хүртэл Еховаг хүндэлж байсан тул улс орон нь бүхэлдээ Бурханаар ерөөгдсөн гэдгийг чи мэдэж авч чадна. Энэ нь Хуучин Гэрээнд бичигдсэн Израилийн түүх билээ.

Библи бол Израиль дахь Бурханы ажлын түүхэн тэмдэглэл бөгөөд эртний эш үзүүлэгчдийн олон зөгнөл, түүнчлэн тухайн үеийн Еховагийн ажил дахь зарим

айлдварыг баримтжуулдаг. Тиймээс хүмүүс бүгд энэ номыг ариун (Бурхан ариун, агуу учраас) гэж үздэг. Мэдээж энэ нь бүгд Еховаг гэх тэдний хүндлэл, Бурханыг гэх тэдний бишрэлийн үр дүн билээ. Бурханы бүтээлүүд Бүтээгчээ маш их хүндэлж, биширдэг учраас л хүмүүс энэ номыг ингэж хэлдэг бөгөөд энэ номыг тэнгэрлэг ном гэж нэрлэдэг хүмүүс ч бий. Үнэндээ энэ нь ердөө л хүний тэмдэглэл юм. Үүнийг Ехова биечлэн нэрлээгүй, биечлэн залж чиглүүлж бүтээгээгүй. Өөрөөр хэлбэл, энэ номын зохиолч нь Бурхан биш, харин хүмүүс юм. Ариун Библи гэдэг нь зөвхөн хүний өгсөн хүндэлсэн нэр юм. Энэ нэрийг Ехова, Есүс хоёр өөр хоорондоо хэлэлцсэний дараа шийдээгүй; энэ нь хүний санаанаас цаашгүй. Учир нь энэ номыг Ехова бичээгүй, Есүс бүр ч бичээгүй. Харин ч энэ нь эртний олон эш үзүүлэгч, элч, болон зөнчдийн өгсөн тайлан бөгөөд дараагийн үеийнхэн нь эртний бичвэрийн ном болгон цэгцэлж, улмаар хүмүүст нэн ариун, хожмын үеийнхний нээхийг хүлээж буй ойлгогдошгүй, гүн гүнзгий нууц агуулсан ном мэт санагддаг. Иймээс хүмүүс энэ ном бол тэнгэрлэг ном мөн гэж бүр ч их итгэх болсон. Дөрвөн Сайн мэдээ болон Илчлэлийн Ном нэмэгдсэнээр үүнд хандах хүмүүсийн хандлага өөр ямар ч номоос тун өөр байдаг бөгөөд улмаар энэ ном дэндүү “ариун” учраас хэн ч энэхүү “тэнгэрлэг номыг” задлан шинжилж зүрхэлдэггүй.

Библийг дөнгөж уншингуутаа хүмүүс яагаад үүн дотроос хэрэгжүүлэх замыг олж чаддаг вэ? Хүмүүсийн ойлгодоггүй ихээхэн зүйлийг тэд яагаад олж авч чаддаг вэ? Өнөөдөр Би ийм маягаар Библийг задлан шинжилж байгаа бөгөөд үүнийг үзэн яддаг, эсвэл лавлагаа болох үнэ цэнийг нь үгүйсгэдэг гэсэн үг биш юм. Мэдэхгүй байгааг чинь болиулахын тулд Би Библийн угийн үнэ цэн болон эх сурвалжийг чамд тайлбарлаж, тодруулж өгч байна. Учир нь хүмүүст Библийн талаар маш олон үзэл байдаг ба тэдгээрийн ихэнх нь буруу юм; Библийг ингэж унших нь олж авах ёстой зүйлдээ хүрэхэд нь тэдэнд саад хийгээд зогсохгүй, үүнээс ч илүүгээр Миний хийхээр зорьдог ажилд саад учруулдаг. Энэ нь хожмын ажлыг асар их үймүүлж, давуу тал бус, зөвхөн сул талыг л бий болгодог. Тиймээс Миний чамд зааж буй зүйл бол ердөө л Библийн мөн чанар, дотоод түүх юм. Би чамаас Библийг битгий унш гэж, эсвэл энэ нь ямар ч үнэ цэнгүй гэдгийг энд тэндгүй тунхагла гэж шаардаж байгаа юм биш, харин Библийн талаар зөв мэдлэг, зөв үзэл бодолтой байхыг л шаардаж байна. Хэтэрхий өрөөсгөл бүү бай! Хэдийгээр Библи нь хүмүүсийн бичсэн түүхийн ном боловч энэ нь бас эртний ариун хүмүүс болон элчүүдийн Бурханд үйлчилж байсан олон зарчим болон сүүлийн үеийн элчүүдийн Бурханд үйлчилсэн туршлагуудыг тэмдэглэдэг—энэ бүхнийг энэ хүмүүс үнэхээр харж, мэдсэн бөгөөд үнэн замыг эрэлхийлж байгаа энэхүү эрин үеийн хүмүүс лавлагаа болгон ашиглаж болно. Тиймээс Библийг уншихдаа хүмүүс өөр номоос олдохгүй амийн олон замыг ч бас олж авч чадна. Эдгээр зам нь өнгөрсөн эрин үеүдийн эш үзүүлэгч, элч нарын туулсан Ариун Сүнсний ажлын амийн замууд бөгөөд ихэнх үг нь үнэ цэнтэйн зэрэгцээ хүмүүсийг хэрэгтэй зүйлээр нь хангаж чадна. Тиймээс хүмүүс бүгдээрээ Библийг унших дуртай байдаг. Библид маш олон зүйл нуугдсан байдаг учраас үүнд

хандах хүмүүсийн үзэл бодол нь агуу сүнслэг хүмүүсийн бичвэрт хандахтай адилгүй. Библи бол хуучин болон шинэ эрин үед Ехова, Есүс хоёрт үйлчилж байсан хүмүүсийн туршлага, мэдлэгийн тэмдэглэл, эмхэтгэл тул дараагийн үеийнхэн үүнээс ихээхэн гэгээрэл, гэрэлтүүлэлт, хэрэгжүүлэх замыг олж авч чадсан билээ. Библи ямар ч агуу сүнслэг хүний бичвэрээс илүү дээр байдгийн шалтгаан нь тэр хүмүүсийн бүх бичвэр Библиэс гардаг, мөн тэдний туршлага бүгд Библиэс бий болдог бөгөөд бүгд Библийг тайлбарладаг. Иймээс, хүмүүс аливаа агуу сүнслэг хүний номоос хангалт олж авч чаддаг хэдий ч Библийг шүтсээр байдаг, учир нь энэ нь тэдний хувьд маш өндөр дээд, гүн гүнзгий санагддаг! Библи нь Паулын захидал, Петрийн захидал гэх мэт амийн үгийн зарим номыг нэгтгэсэн хэдий ч, мөн хүмүүс эдгээр номын хангалт, дэмжлэгийг хүртдэг ч эдгээр ном хоцрогдсон хэвээр, хуучин эрин үед харьяалагддаг хэвээр бөгөөд тэдгээр нь хэчнээн сайн байх нь хамаагүй, үүрд мөнхөд биш, зөвхөн нэг цаг үед л тохиромжтой байдаг. Учир нь Бурханы ажил үргэлж хөгжиж байдаг ба Паул, Петр хоёрын цаг үед зүгээр л зогсчихож болохгүй, эсвэл Есүсийн цовдлогдсон Нигүүлслийн эрин үед үргэлж үлдэхгүй. Иймээс эдгээр ном нь эцсийн өдрүүдийн Хаанчлалын эрин үед биш, зөвхөн Нигүүлслийн эрин үед л тохиромжтой. Тэдгээр нь Хаанчлалын эрин үеийн ариун хүмүүс биш, Нигүүлслийн эрин үеийн итгэгчдийг л хангаж чадах бөгөөд хэчнээн сайн байлаа ч, хоцрогдсон хэвээр юм. Еховагийн бүтээлийн ажил, эсвэл Израиль дахь Түүний ажлын хувьд ч энэ нь адилхан: Энэ ажил нь хэчнээн агуу байсан ч, мөн л хоцрогдсон байх бөгөөд энэ бүхэн өнгөрөх одох цаг мөн л ирнэ. Бурханы ажил ч бас адилхан: Энэ нь агуу боловч дуусах цаг ирнэ; энэ нь үргэлж бүтээлийн ажил дунд, эсвэл цовдолын ажил дунд үлдэж чадахгүй. Цовдлолын ажил хэчнээн үнэмшилтэй байсан ч, Сатаныг ялахад хэчнээн үр нөлөөтэй байсан ч, эцсийн эцэст ажил бол ажил, эрин үе бол эрин үе юм; ажил үргэлж нэг суурин дээрээ байж чадахгүй, мөн цаг хугацаа хэзээ ч өөрчлөгдөхгүй байж ч чадахгүй, бүтээл байсан учраас эцсийн өдрүүд байх ёстой. Энэ бол зайлшгүй! Тиймээс өнөөдөр Шинэ Гэрээн дэх амийн үг буюу элчүүдийн захидлууд болон Дөрвөн Сайн мэдээ нь түүхэн ном болсон, тэдгээр нь хуучин он дарааллын бичиг болсон, тэгвэл хуучин он дарааллын бичиг хүмүүсийг яаж шинэ эрин үед аваачиж чадах билээ? Эдгээр он дарааллын бичиг хүмүүсийг амиар хангах чадвартай байх нь хамаагүй, хүмүүсийг загалмай руу хөтлөх чадвартай байх нь хамаагүй, тэдгээр нь хуучирсан бус уу? Үнэ цэнгүй бус уу? Тиймээс Би, эдгээр он дарааллын бичигт сохроор бүү итгэ гэж чамд хэлье. Тэдгээр нь хэтэрхий хуучин, чамайг шинэ ажил руу аваачиж чадахгүй бөгөөд чамд зөвхөн ачаа л болно. Тэгээд чамайг шинэ ажил, шинэ оролт руу аваачиж чадахгүйгээр үл барам, шашны хуучин чуулгануд руу аваачна—тэгэх юм бол чи Бурханд итгэх итгэлдээ ухарч байгаа хэрэг бус уу?

Библи нь Израилийн сонгогдсон ард түмний хийсэн зүйлийн заримыг оролцуулаад Израиль дахь Бурханы ажлыг баримтжуулдаг. Зарим хэсгийг нь багтааж, эсвэл хассан баримтыг үл харгалзан, Ариун Сүнс зөвшөөрөөгүй ч огт буруутгаагүй. Библи бол

гагцхүү Израилийн түүх, бас Бурханы ажлын түүх билээ. Үүнд бичигдсэн хүмүүс, хэрэг явдал, аливаа зүйлс бүгд бодитой бөгөөд мэдээж Исаиа, Даниел болон бусад эш үзүүлэгчийн зөгнөл, эсвэл Иоханы үзэгдлийн номоос бусдынх нь хувьд аль нь ч бэлгэдлийн утгатай байгаагүй. Израилийн эхэн үеийн хүмүүс мэдлэгтэй, соёлтой байсан бөгөөд эрт дээр үеийн мэдлэг болон соёл нь нэлээд дэвшилттэй байсан тул тэдний бичсэн зүйл өнөөдрийн хүмүүсийн бичдэг зүйлээс илүү өндөр түвшинд байсан юм. Үүний үр дүнд, тэд эдгээр номыг бичсэнд гайхах юмгүй, учир нь Ехова тэдний дунд маш их ажил хийж, тэд маш ихийг харсан билээ. Давид Еховагийн үйл хэргийг нүдээрээ харж, биечлэн туулж, олон тэмдэг гайхамшиг харсан, иймээс тэр Еховагийн үйл хэргийг магтан тэр бүх дууллыг бичсэн юм. Тэд тодорхой нөхцөл байдалд эдгээр номыг бичиж чадсан болохоос ер бусын авьяастай байснаас болоогүй юм. Тэд Еховаг харсан учраас магтсан. Хэрвээ та нар Еховагийн юуг ч хараагүй, Түүний оршин тогтнолыг мэддэггүй бол яаж Түүнийг магтаж чадах юм бэ? Хэрвээ та нар Еховаг хараагүй бол Түүнийг магтахаа мэдэхгүй, Түүнд шүтэн мөргөхгүй, тэр ч бүү хэл, Түүнийг шагшин магтсан дуу зохиож чадахгүй бөгөөд Еховагийн зарим үйл хэргийг зохиохыг та нараас хүссэн ч тэгж чадахгүй байх болно. Өнөөдөр та нар Бурханыг магтаж, Бурханыг хайрлаж чадаж байгаа нь ч бас Түүнийг харж, Түүний ажлыг туулснаас болдог бөгөөд хэрвээ хэв чанар чинь сайжирвал та нар ч бас Давидын адилаар Бурханыг магтсан шүлэг бичиж чадах бус уу?

Библийг ойлгож, түүхийг ойлгодог боловч Ариун Сүнс өнөөдөр юу хийж байгааг ойлгохгүй байх нь буруу юм! Чи түүхийг маш сайн судалж, гайхалтай ажил хийсэн ч Ариун Сүнсний өнөөдөр хийдэг ажлын талаар юу ч ойлгодоггүй. Энэ нь мунхаглал бус уу? Бусад хүмүүс чамаас: “Бурхан өнөөдөр юу хийж байгаа вэ? Өнөөдөр чи юунд орох ёстой вэ? Амийн эрэл хайгуул чинь ямархуу байна вэ? Чи Бурханы хүслийг ойлгодог уу?” гэж асуудаг. Тэдний асуултад өгөх хариулт чамд байхгүй байх болно—тэгвэл чи юу мэддэг вэ? “Би махан биеэ орхиж, өөрийгөө мэдэх ёстой гэдгээ л мэднэ” гэж чи хариулна. Тэгээд хэрвээ тэд “Чи өөр юу мэддэг вэ?” гэж асуувал чи, Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагах ёстой, Библийн түүхийг бага зэрэг ойлгох ёстой гэдгийг мэднэ, тэгээд л тэр гэж хэлнэ. Энэ олон жил Бурханд итгээд олж авсан бүх зүйл чинь энэ үү? Хэрвээ чи үүнийг л ойлгодог бол маш дутуу дулимаг байна. Тиймээс одоогийн биеийн хэмжээ чинь үндсэндээ та нараас Миний шаарддаг зүйлийг биелүүлэх чадваргүй бөгөөд ойлгодог үнэн чинь ялган таних чадварын чинь хамтаар хэтэрхий хомс—өөрөөр хэлбэл, та нарын итгэл дэндүү өнгөцхөн! Та нар илүү их үнэнээр зэвсэглэх ёстой, та нарт илүү их мэдлэг хэрэгтэй, та нар илүү ихийг харах ёстой бөгөөд тэр үед л та нар сайн мэдээ түгээж чадна, учир нь энэ бол та нарын хүрэх учиртай зүйл юм!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 1

Урьд нь хүмүүсийн туршлагажих байдалд ихээхэн гажуудал, тэр ч бүү хэл төөрөгдөл байдаг байв. Тэд зүгээр л Бурханы шаардлагын стандартыг ойлгоогүй тул олон талбарт хүмүүсийн туршлага гажуудсан юм. Бурхан хэвийн хүн чанарыг амьдран харуулах чадвартай байхыг л хүнээс шаарддаг. Жишээлбэл, хүмүүс хоол хүнс, хувцаслалттай холбоотой орчин үеийн ёс заншлыг дагаж, костюм өмсөж, зангиа зүүж, орчин үеийн урлагийн талаар бага зэрэг суралцаж, чөлөөт цагаараа урлаг, соёл, үзвэр үйлчилгээ таашаан соёрхож болно. Тэд дурсамжтай зураг авч, ном уншиж, хэрэгтэй мэдлэгээ олж авч, харьцангуй сайн амьдрах орчинтой байж болно. Энэ нь хэвийн хүн чанарын амьдралд тохирдог бүх зүйл боловч хүмүүс эдгээрийг Бурханы жигшдэг зүйл мэт үзэн, тэдгээрийг хийхээс татгалздаг. Тэдний хэрэгжүүлэлт ердөө хэдхэн дүрэм журмыг дагахаас бүрддэг бөгөөд энэ нь ямар ч утга учиргүй, залхмаар уйтгартай амьдрал руу хөтөлдөг. Үнэндээ Бурхан хүмүүсээс аливааг ийм маягаар хий гэж хэзээ ч шаардаагүй. Хүмүүс бүгд зан чанараа хязгаарлахыг хүсэж, Бурханд ойр байхын тулд сүнсэндээ тасралтгүй залбирч, оюун ухаан нь Бурханы зорьж буй зүйлсийг байнга тунгаан бодож, нүд нь энэ тэрийг тасралтгүй ажиглаж, Бурхантай харилцах харилцаа нь ямар нэгэн байдлаар тасрах вий гэдгээс асар их эмээж байдаг. Эдгээр нь бүгд хүмүүсийн өөрсдөө гаргасан дүгнэлт юм; тэдгээр нь хүмүүсийн өөрсдөдөө зориулж тогтоосон дүрэм журам билээ. Хэрвээ чи өөрийнхөө уг чанар-мөн чанарыг мэддэггүй, хэрэгжүүлэлт чинь ямар түвшинд хүрч чадахыг ойлгодоггүй бол хүнээс Бурханы шаарддаг стандарт яг юу болохыг лавтай мэдэх ямар ч аргагүй байна, мөн хэрэгжүүлэлтийн үнэн зөв зам ч чамд байхгүй байна. Мөн хүнээс Бурханы шаарддаг зүйл яг юу болохыг чи ойлгож чаддаггүй тул оюун санаа чинь үргэлж эргэж байдаг ба Бурханы санаа зорилгыг задлан шинжлэхээр тархиа гашилган, Ариун Сүнсээр сэтгэлээ хөдөлгүүлж, гэгээрүүлэгдэх арга замыг хайн тэмтэчдэг. Үүний үр дүнд чи тохиромжтой гэж бодсон, хэрэгжүүлэлтийн зарим арга замыг бий болгодог. Бурхан хүнээс яг юу шаарддагийг чи ер мэддэггүй; чи зүгээр л санаа зовох юмгүйгээр өөрийнхөө цогц хэрэгжүүлэлтийг гүйцэтгэн, үр дүнгийн талаар багахан анхаардаг ба хэрэгжүүлэлтэд чинь гажуудал юм уу алдаа мадаг байгаа эсэхийг бүр ч тоодоггүй. Ийм маягаар, хэрэгжүүлэлтэд чинь үнэн зөв байдал аяндаа дутагддаг бөгөөд зарчимгүй байдаг. Үүнд ялангуяа, хүний хэвийн эрүүл ухаан, мөс чанар, Бурханы сайшаал, Ариун Сүнсний баталгаа дутагддаг. Ийм хэрэгжүүлэлт нь ердөө дүрэм журам дагаж байгаа хэрэг буюу өөрийгөө хязгаарлаж, хянахын тулд зориуд илүү их ачаа үүрч байгаа хэрэг юм. Гэвч хэрэгжүүлэлтийн чинь ихэнх нь хэрэггүй үйл явц юм уу зан үйл гэдгийг мэдэлгүйгээр чи өөрийнхөө хэрэгжүүлэлтийг нарийн нягт гэж боддог. Үндсэндээ зан чанарын ямар ч өөрчлөлтгүй, ямар ч шинэ ойлголтгүй, ямар ч шинэ оролтгүйгээр олон жилийн турш ингэж хэрэгжүүлдэг олон хүн бий. Тэд олон удаа бодлогогүй, хүний үнэргүй үйл үйлдэн, хүмүүсийг будилуулж, бүрмөсөн

мухардуулах байдлаар авирлах хэмжээнд очих хүртлээ нэгэн хэвийн хуучин алдаагаа давтаж, хэрцгий догшин уг чанараа бүрэн ашигладаг. Ийм хүмүүсийг зан чанарын өөрчлөлт туулсан гэж хэлж болох уу?

Одоо, Бурханд итгэх итгэл Бурханы үгийн эрин үед оржээ. Харьцуулан хэлбэл, хүмүүс урьдынх шигээ их залбирдаггүй; Бурханы үг, үнэний бүх тал болон хэрэгжүүлэлтийн замыг тодорхой хэлж өгсөн тул хүмүүс цаашид эрж хайж, тэмтчих хэрэггүй болсон. Хаанчлалын эрин үеийн амьдралд Бурханы үг хүмүүсийг урагш хөтөлдөг бөгөөд энэ нь хүмүүст бүхнийг тодорхой харуулдаг амьдрал юм—учир нь Бурхан бүхнийг ил тод болгосон бөгөөд хүн амьдралд замаа тэмтчин үлдэхээ больсон. Гэрлэлт, дэлхий ертөнцийн хэрэг явдал, амьдрал, хоол унд, хувцас, орон байр, хүмүүсийн хоорондын харилцаа, хүн Бурханы хүслийг хангаж чадахуйцаар хэрхэн үйлчлэх, хэрхэн махан биеэ хаях ёстой гэх мэт зүйлээс алийг нь Бурхан та нарт тайлбарлаж өгөөгүй вэ? Та нар одоо ч гэсэн залбирч, эрж хайхаар явах хэрэгтэй юу? Үнэндээ огт хэрэггүй! Хэрвээ эдгээр зүйлийг хийсээр байгаа бол чи зүгээр л илүүц юм хийж байна. Энэ нь мэдлэггүй, мунхаг хэрэг бөгөөд ямар ч хэрэггүй! Хэв чанараар хэтэрхий дутмаг, Бурханы үгийг ойлгож чаддаггүй хүмүүс л мунхгаар залбирсаар байдаг. Үнэнийг хэрэгжүүлэх гол түлхүүр нь чамд шийдвэр байгаа юу, үгүй юу гэдэг юм. Зарим хүн, үнэнтэй нийцдэггүй гэдгийг нь мэдэж байсан ч гэсэн үйлдэлдээ махан биеийн дур сонирхлыг дагахаар зүтгэдэг. Тэгээд энэ нь тэдний амийн ахиц дэвшилд саад учруулдаг бөгөөд залбирч, эрж хайсныхаа дараа ч гэсэн тэд махан биед дуулгавартай авирлахыг хүссээр байдаг. Ингэснээрээ тэд өөрийн мэдэлгүй нүгэл үйлдэж байгаа бус уу? Махан биеийн зугаа цэнгэлд шунаж, мөнгийг хүсэмжилж, дараа нь “Бурхан минь! Та надад бие махбодын зугаа цэнгэл болон эд баялагт шунахыг зөвшөөрөх үү? Ийм маягаар мөнгө олох нь надад зориулсан Таны хүсэл мөн үү?” гэж Бурханд залбирдаг хүмүүстэй адил бус уу? Энэ нь залбирах зүй зохистой арга зам мөн үү? Ингэдэг хүмүүс, Бурхан эдгээр зүйлд огтхон ч баярладаггүй, тэдгээрийг хаях ёстой гэдгийг тун сайн мэдэж байдаг боловч зүрх сэтгэлдээ хадгалдаг зүйлс нь аль хэдийн тогтсон байдаг бөгөөд залбирч, эрж хайх үедээ тэд Бурханыг хүчлэн ийм маягаар авирладгаа зөвшөөрүүлэхээр оролддог. Зүрх сэтгэлдээ тэд бүр үүнийг нь батлах ямар нэг зүйл хэлэхийг Бурханаас шаардаж ч магад—үүнийг тэрслүү байдал гэж нэрлэдэг. Бас чуулганы ах эгч нарыг өөрсдийнхөө талд оруулж, өөрсдийн бие даасан хаанчлалыг байгуулдаг хүмүүс ч бий. Эдгээр үйлдэл Бурханыг эсэргүүцдэгийг чи тун сайн мэддэг ч иймэрхүү зүйл хийхээр шийдмэгцээ тайвнаар, аймшиггүйгээр эрж хайж, Бурханд залбирсаар л байдаг. Ямар ичгүүр сонжуургүй, увайгүй юм бэ! Дэлхий ертөнцийн зүйлсийг орхих тухайд бол үүнийг аль эрт ярьчихсан. Бурхан дэлхий ертөнцийн зүйлсийг үзэн яддаг гэдгийг тодорхой мэддэг атлаа мөн л залбирч: “Өө Бурхан минь! Та дэлхий ертөнцийн зүйлсэд автахыг минь зөвшөөрөхгүй гэдгийг би ойлгож байна, гэхдээ би Таны нэрийг шившиглэхгүй гэсэндээ л үүнийг хийдэг; мөн дэлхий ертөнцийн хүмүүс Таны алдрыг надаас

хараасай гэсэндээ үүнийг хийдэг” гэж хэлдэг зарим хүн бий. Энэ нь ямар төрлийн залбирал вэ? Та нар хэлж чадах уу? Энэ нь Бурханыг албадаж, Бурханд дарамт үзүүлэхээр зорьдог залбирал юм. Чи ийм маягаар залбирахаас ичихгүй байна уу? Ийм маягаар залбирдаг хүмүүс Бурханыг зориуд эсэргүүцдэг ба иймэрхүү залбирал нь тэр чигтээ эргэлзээтэй сэдлийн асуудал юм; энэ нь үнэхээр сатанлаг зан чанарын илэрхийлэл билээ. Бурханы үг, ялангуяа Түүний хүсэл, зан чанар болон өөр өөр төрлийн хүмүүст Тэр яаж ханддаг талаар айлдсан үг нь тов тодорхой байдаг. Хэрвээ чи үнэнийг ойлгодоггүй бол Бурханы үгийг илүү их унших ёстой—ингэсний үр дүн нь сохроор залбирч, эрж хайснаас хавьгүй илүү байдаг. Эрж хайж, залбирах явдлыг Бурханы үгийг илүү их уншиж, үнэний талаар нөхөрлөх явдлаар солих ёстой олон тохиолдол байдаг. Ердийн залбиралдаа чи өөрийгөө эргэцүүлж, Бурханы үгэн дотроос өөрийгөө мэдэхээр хичээх ёстой. Энэ нь амийн ахиц дэвшилд чинь илүү ашиг тустай. Хэрвээ чи одоо ч гэсэн тэнгэр өөд харцаа өргөн эрж хайдаг тодорхойгүй Бурханд итгэсээр байгааг чинь энэ нь харуулдаггүй гэж үү? Урьд нь чи өөрийн эрэл хайгуул болон залбирлын үр дүнг харсан бөгөөд тэр үе нь Нигүүлслийн эрин үе байсан учраас Ариун Сүнс ямар нэгэн байдлаар сүнсийг чинь хөдөлгөсөн. Чи Бурханыг харж чадаагүй тул урагшлах замаа тэмтэрч, тийм маягаар эрж хайхаас өөр аргагүй байсан. Одоо Бурхан хүмүүсийн дунд ирж, Үг махбодоор илэрсэн бөгөөд чи Бурханыг харсан; тиймээс Ариун Сүнс урьдынх шигээ ажиллахаа больдог. Эрин үе өөрчлөгдсөн болохоор Ариун Сүнсний ажилладаг арга зам ч өөрчлөгдсөн. Хүмүүс урьдынх шигээ их залбирахгүй байгаа байж магад хэдий ч Бурхан газар дээр байгаа учраас одоо хүнд Бурханыг хайрлах боломж байгаа. Хүн төрөлхтөн Бурханыг хайрлах эрин үед орсон ба дотроо Бурхантай хэвийн байдлаар ойр дотно болж чадна: “Өө Бурхан минь! Та үнэхээр маш сайн, би Таныг хайрлахыг хүсэж байна!” Зүгээр л цөөн хэдэн тодорхой, энгийн үг хүмүүсийн зүрх сэтгэл доторх Бурханыг гэх хайрыг илэрхийлдэг; Бурхан хүн хоёрын хоорондох хайрыг гүнзгийрүүлэхийн төлөө л энэ залбирлыг хэлдэг. Заримдаа чи бага зэргийн тэрслүү байдал илэрхийлж байгаагаа хараад, “Өө Бурхан минь! Би яагаад ийм завхарсан юм бэ?” гэж хэлж болох юм. Чи өөрийгөө хэд хэдэн удаа алгадахыг үнэхээр хүсэж, нүдэнд чинь нулимс цийлгэнэдэг. Ийм үед зүрх сэтгэлдээ чи харуусаж, бачимддаг боловч эдгээр мэдрэмжээ илэрхийлэх ямар ч аргагүй байдаг. Энэ нь Ариун Сүнсний одоогийн ажил юм, гэхдээ амийг эрэлхийлдэг хүмүүс л үүнд хүрч чаддаг. Бурхан чамайг асар их хайрладаг гэдгийг чи мэдэрч, чамд ер бусын мэдрэмж төрдөг. Чамд тодорхой залбирах үг байхгүй ч Бурханы хайр бол далай мэт гүн гэдгийг үргэлж мэдэрдэг. Энэ байр байдлыг илэрхийлэх тохиромжтой үг нэг ч үгүй бөгөөд энэ бол үргэлж сүнсэн дотроос гарч ирдэг байр байдал билээ. Зүрх сэтгэлдээ Бурхантай ойртохыг зорьдог ийм төрлийн залбирал, нөхөрлөл нь хэвийн юм.

Хэдийгээр хүмүүс тэмтэрч, эрж хайх ёстой байсан цаг үе одоо өнгөрсөн ч тэд цаашид залбирч, эрж хайх хэрэггүй гэсэн үг биш, мөн ажлаа үргэлжлүүлэхээсээ

өмнө Бурханы хүсэл аяндаа илчлэгдэхийг хүлээх хэрэггүй гэсэн үг ч биш; эдгээр нь зүгээр л хүний буруу ойлголт юм. Бурхан хүмүүстэй хамт амьдарч, тэдний гэрэл, амь, зам байхаар дунд нь ирсэн: Энэ нь бодит баримт мөн. Мэдээж, Бурхан газар дээр ирэхдээ хүмүүсээр эдлүүлэхийн тулд биеийн хэмжээнд нь тохирох бодитой зам болон амийг гарцаагүй авчирдаг—Тэрээр хүний хэрэгжүүлэлтийн бүх арга замыг эвдэхийн тулд ирээгүй. Хүн цаашид тэмтэрч, эрж хайн амьдрахгүй, учир нь Бурхан ажиллаж, Өөрийн үгийг хэлэхийн тулд газар дээр ирсэн нь эдгээрийг орлосон билээ. Тэрээр хүнийг харанхуй, тодорхой бус амьдралаас нь чөлөөлж, амьдралыг нь гэрлээр дүүргэхийн тулд ирсэн. Одоогийн ажил бол аливааг тодорхой заан үзүүлж, тодорхой ярьж, шууд мэдэгдэж, аливааг илэн далангүй тодорхойлохын төлөө байдаг болохоор Ехова Бурхан Израилийн ард түмнийг залж чиглүүлж, хэрхэн тахил өргөж, сүм барихыг тэдэнд хэлж өгсөнтэй адилаар хүмүүс эдгээр зүйлийг хэрэгжүүлж чадах юм. Тиймээс та нар Эзэн Есүсийг явсны дараах шигээ чин сэтгэлээсээ эрж хайсан амьдралаар амьдрах хэрэггүй. Та нар ирээдүйд сайн мэдээ түгээх ажлаар дамжуулан замаа тэмтрэх ёстой юу? Амьдрах зүй зохистой арга замыг олохоор оролдон тэмтчих хэрэгтэй юу? Үүргээ хэрхэн биелүүлэх ёстойгоо ялган танихын тулд тэмтчин явах ёстой юу? Та нарын хувьд нүүрээрээ газар унан мөргөж, яаж гэрчлэл хийх ёстойгоо мэдэхийн тулд эрж хайх шаардлагатай юу? Хэрхэн хувцаслаж, хэрхэн амьдрах ёстойгоо мэдэхийн тулд мацаг барьж, залбирах шаардлагатай юу? Бурханаар байлдан дагуулагдах явдлыг хэрхэн хүлээн зөвшөөрөх ёстойгоо мэдэхийн тулд тэнгэр дэх Бурханд тасралтгүй залбирах шаардлагатай юу? Бурханд хэрхэн дуулгавартай байх ёстойгоо мэдэхийн тулд өдөржин, шөнөжин тасралтгүй залбирах шаардлагатай юу? Та нарын дунд, ойлгодоггүй учраас хэрэгжүүлж чадахгүй гэж хэлдэг хүмүүс олон бий. Хүмүүс Бурханы өнөөгийн ажилд ердөө анхаарал хандуулахгүй байгаа! Би аль хэдийн олон үг хэлсэн боловч та нар тэдгээрийг уншихад өчүүхэн ч анхаарал хандуулаагүй, иймээс яаж хэрэгжүүлэхээ мэдэхгүй байгааг чинь гайхах хэрэггүй. Мэдээж, өнөөгийн эрин үед хүмүүст таашаал олгохын тулд Ариун Сүнс мөн л хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, хүнтэй хамт амьдардаг. Энэ нь амьдралд чинь үргэлж тохиолддог онцгой, тааламжтай тэр[a] мэдрэмжүүдийн эх сурвалж юм. Бурхан тун хайр татам гэдгийг мэдрэх өдөр хааяа ирдэг бөгөөд чи өөрийн эрхгүй Түүнд ийнхүү залбирдаг: “Өө Бурхан минь! Таны хайр маш сайхан, Таны дүр маш агуу. Би Таныг улам илүү гүнзгий хайрлахыг хүсэж байна. Би амьдралаа бүхэлд нь зарлагадахын тулд өөрийгөө тэр чигт нь зориулахыг хүсэж байна. Таны төлөө л байх юм бол, мөн ингэснээрээ би Таныг хайрлаж чадах л юм бол, би бүх зүйлийг Танд зориулна…” Энэ бол Ариун Сүнснээс та нарт өгсөн таатай мэдрэмж юм. Энэ нь гэгээрэл биш, гэрэлтүүлэлт ч биш; энэ бол сэтгэл хөдөлж буй туршлага мөн. Ийм төрлийн туршлага хааяа хааяа тохиолдоно: Заримдаа ажилдаа явах замдаа

[a] Эх бичвэрт “Эдгээр нь зарим” гэж байдаг.

чи залбирч, Бурханд ойртож, улмаар нулимс нүүрийг чинь норгон, хяналтаа алдах хүртлээ сэтгэл хөдлөх бөгөөд зүрх сэтгэл доторх бүх ааг омгоо илэрхийлэхэд тохиромжтой орчныг олохоор эрмэлздэг… Олон нийтийн газарт байхдаа, Бурханы хайрыг маш их эдэлж байгаа, заяа төөрөг чинь энгийн биш, үүнээс ч илүүтэйгээр чи өөр хэнээс ч илүү утга учиртай амьдралаар амьдарч байна гэж чамд санагдах үе байх болно. Бурхан чамайг өргөмжилснийг, энэ нь чамайг гэсэн Бурханы агуу хайр болохыг чи гүнээ мэднэ. Хүний хувьд үгээр илэрхийлж, ухан ойлгох аргагүй хайр Бурханд байдгийг чи зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэрнэ, чи үүнийг мэдэж байгаа ч дүрслэн хэлэх ямар ч аргагүй мэт байдаг бөгөөд энэ нь чамд үргэлж юм бодогдуулдаг ч үүнийг бүрэн дүүрэн илэрхийлэх чадваргүй болгож орхидог. Иймэрхүү үед чи хаана байгаагаа ч мартах бөгөөд: “Өө Бурхан минь! Та үнэхээр ойлгогдошгүй, бас маш хайр татам!” гэж дуу алддаг. Энэ нь хүмүүсийг гайхшируулж орхино, гэхдээ ийм зүйл нэлээд олон удаа тохиолддог. Та нар иймэрхүү зүйлийг маш олон удаа туулсан. Энэ бол өнөөдөр Ариун Сүнсний чамд өгсөн амьдрал, одоо чиний амьдрах ёстой амьдрал юм. Энэ нь амьдрахыг чинь болиулахын төлөө байдаггүй, харин ч амьдардаг байдлыг чинь өөрчлөхийн төлөө байдаг. Энэ нь дүрслэн хэлж, илэрхийлэх аргагүй мэдрэмж билээ. Энэ нь бас хүний жинхэнэ мэдрэмж, үүнээс ч илүүтэйгээр Ариун Сүнсний ажил юм. Чи үүнийг зүрх сэтгэлдээ ойлгож болох боловч хэн нэгэнд тодорхой илэрхийлж огт чаддаггүй. Энэ нь удаан ярьдаг, эсвэл гацаж ээрдгээс чинь болдоггүй, харин үгээр дүрслэн хэлж болшгүй мэдрэмж учраас тэр юм. Өнөөдөр эдгээр зүйлийг эдлэхийг чамд зөвшөөрдөг бөгөөд энэ бол чиний амьдрах ёстой зам билээ. Мэдээж чиний амьдралын бусад тал хоосон биш; зүгээр л сэтгэл хөдлөх ийм туршлага амьдралын чинь баяр хөөр болж, Ариун Сүнснээс ийм туршлага эдлэхийг үргэлж хүсэхэд хүргэдэг. Гэхдээ ийм байдлаар хөдөлгөгдөх нь махан биеийг даван гарч, гуравдагч тэнгэр лүү явж, эсвэл дэлхий даяар аялахын төлөө биш гэдгийг чи мэдэх ёстой. Харин ч өнөөдөр өөрийн эдэлдэг Бурханы хайрыг мэдэрч, амталж, Бурханы ажлын өнөөдрийн ач холбогдлыг туулж, Бурханы халамж, хамгаалалтыг мэддэг болохын төлөө байдаг гэдгийг чи мэдэх ёстой. Энэ бүх зүйл нь чамайг Бурханы өнөөдөр хийдэг ажлын талаар илүү их мэдлэгтэй болгохын төлөө байдаг—энэ бол энэхүү ажлыг хийх Бурханы зорилго билээ.

Эрж хайж, тэмтчих нь Бурхан бие махбодтой болохоос өмнөх амьдралын хэв маяг байсан. Тухайн үед хүмүүс Бурханыг харж чадаагүй тул эрж хайж, тэмтчихээс өөр аргагүй байсан юм. Өнөөдөр чи Бурханыг харсан ба Тэр чамд хэрхэн хэрэгжүүлэх ёстойг шууд хэлдэг; ийм учраас чи цаашид тэмтчиж, эсвэл эрж хайх хэрэггүй. Хүнийг хөтөлдөг Түүний зам бол үнэний зам бөгөөд хүнд Түүний хэлдэг зүйл, хүний хүлээн авдаг зүйл нь амь болон үнэн юм. Чамд зам, амь, үнэн байгаа, тэгвэл хаа сайгүй хайхаар явах ямар хэрэгтэй юм бэ? Ариун Сүнс ажлын хоёр үе шатыг нэгэн зэрэг хийхгүй. Хэрвээ Намайг үгээ хэлж дуусах үед хүмүүс Бурханы үгийг анхааралтай идэж ууж, үнэнийг зохих ёсоор эрэлхийлэлгүй, Нигүүлслийн

эрин үеийнхтэйгээ адил авирлаж, сохор юм шиг тэмтчин, байнга залбирч, эрж хайсаар байх юм бол Миний ажлын энэ үе шат буюу үгийн ажил хий дэмий хийгдэж байгаа гэсэн үг биш үү? Хэдийгээр Би үгээ хэлж дууссан байж болох ч хүмүүс мөн л бүрэн дүүрэн ойлгодоггүй бөгөөд энэ нь тэдний хэв чанар дутмагаас болдог. Энэ асуудлыг чуулганы амьдралаар амьдарч, бие биетэйгээ нөхөрлөснөөр дамжуулан шийдвэрлэж болно. Өмнө нь, Нигүүлслийн эрин үед Бурхан бие махбодтой болсон хэдий ч үгийн ажил хийгээгүй, ийм учраас ажлыг хадгалахын тулд Ариун Сүнс тухайн үед тийм маягаар ажилласан. Тэр үед үндсэндээ Ариун Сүнс л ажил хийсэн боловч одоо бие махбодтой болсон Бурхан Өөрөө Ариун Сүнсний ажлын байрыг эзлэн үүнийг хийж байгаа. Урьд нь, хүмүүс байнга залбирч л байх юм бол амар амгалан, баяр хөөрийг мэдэрдэг байсан; зэмлэл, сахилгажуулалт ч бас байсан. Энэ нь бүгд Ариун Сүнсний ажил байсан юм. Одоо эдгээр байр байдал ховорхон. Ариун Сүнс аль нэг эрин үед зөвхөн нэг төрлийн ажил л хийж чадна. Хэрвээ Тэрээр хоёр өөр ажлыг нэгэн зэрэг хийж, махбод нь нэг төрлийн ажил хийж, Ариун Сүнс хүмүүсийн дотор өөр нэгийг хийсэн бол, мөн махбодын хэлсэн зүйл тооцогдолгүй, Ариун Сүнсний хийсэн зүйл л тооцогдож байсан бол Христэд яриад байх ямар ч үнэн, зам, амь байхгүй байх байв. Энэ нь дотоод зөрчил байх байлаа. Ариун Сүнс ингэж ажиллаж чадах уу? Бурхан бол төгс хүчит, бүхэлдээ ухаалаг, ариун, зөвт бөгөөд Тэр яавч алдаа гаргадаггүй.

Хүмүүсийн урьдын туршлагад хэтэрхий их гажуудал, алдаа мадаг байсан. Хэвийн хүн чанартай хүмүүст байх учиртай, тэдний хийх учиртай зарим зүйл байсан буюу хүний амьдралд зайлсхийхэд хэцүү алдаа байдаг байсан бөгөөд эдгээр зүйл муугаар эргэх үед хүмүүс хариуцлагыг нь Бурханд тохсон. Нэг эгчийн гэрт зочид иржээ. Түүний жигнэсэн мантуу зөв хөөгөөгүй болохоор тэр эгч: “Энэ нь магадгүй Бурханы сахилгажуулалт байх. Бурхан биеэ тоосон зүрх сэтгэлтэй минь дахиад харьцаж байна; миний нэрэлхүү зан үнэхээр дэндүү их юм” гэж бодож. Үнэндээ хүний хэвийн сэтгэхүйн үүднээс бол зочид ирэх үед чи баярлан хөөрч, яаравчилж, хийж байгаа бүхнээ хольж хутгадаг, иймээс будаа чинь түлэгдэх юм уу хоол чинь хэтэрхий шорвог болж таарах нь мэдээжийн хэрэг. Энэ нь хэтэрхий их сэтгэл хөдөлснөөс болдог боловч хүмүүс үүнийг “Бурханы сахилгажуулалт” руу тохож дуусдаг. Үнэндээ эдгээр нь бүгд ердөө хүний амьдралд гардаг алдаа мадаг юм. Хэрвээ чи Бурханд итгээгүй бол ийм төрлийн зүйлтэй бас л олон дахин тулгарахгүй гэж үү? Тохиолддог асуудлууд нь үргэлж хүмүүсийн гаргасан алдааны үр дүн байдаг—ийм алдаануудыг Ариун Сүнс гаргадаг юм биш. Ийм алдаа нь Бурхантай ямар ч хамаагүй. Жишээ нь чи юм идэж байгаад хэлээ хазвал—энэ нь Бурханы сахилгажуулалт байж болох уу? Бурханы сахилгажуулалтад зарчим байдаг бөгөөд энэ нь ихэвчлэн зориуд зөрчил гаргах үед харагддаг. Бурханы нэрийг агуулсан, эсвэл Түүний гэрчлэл юм уу ажилтай холбоотой зүйлийг хийх үед чинь л Тэр чамайг сахилгажуулна. Одоо хүмүүс өөрсдийн хийдэг зүйлсийн талаар дотроо мэддэг байхад хангалттай үнэнийг ойлгодог. Жишээлбэл: Хэрвээ чи

чуулганы мөнгийг шамшигдуулж, эсвэл үүнийг бодлогогүй зарцуулсан бол юу ч мэдрэхгүй байж чадах уу? Тийм зүйл хийх үедээ чи ямар нэгэн зүйлийг мэдэрнэ. Үйл хэрэг дуусмагц л ямар нэгэн зүйлийг мэдрэх боломжгүй. Мөс чанарт чинь харшилдаг зүйл хийсэн тухайгаа чи зүрх сэтгэлдээ тодорхой мэдэж байдаг. Хүмүүст өөрсдийн гэсэн дуртай зүйл, шилэлт сонголт байдаг учраас тэд үнэнийг хэрхэн хэрэгжүүлэхээ тодорхой мэдэж байсан ч гэсэн зүгээр л өөрсдийгөө өөгшүүлдэг. Ийм болохоор ямар нэгэн зүйл хийснийхээ дараа тэд илт зэмлэлийг мэдэрдэггүй, илэрхий сахилгажуулалт ч туулдаггүй. Тэд мэдсээр байж зөрчил гаргасан тул Бурхан тэднийг сахилгажуулдаггүй; зөвт шүүлтийн цаг ирмэгц хийсэн үйлдлүүдийнх нь дагуу хүн бүхэнд Бурханы залхаан цээрлүүлэлт хүрнэ. Одоогоор, мөнгө шамшигдуулдаг зарим хүн чуулганд байдаг, мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд тодорхой зааг барьдаггүй зарим хүн, Бурханы ажлыг нууцаар шүүж, эсэргүүцэж, нураахаар оролддог зарим хүн бий. Гэтэл яагаад энэ бүхэн тэдний хувьд зүгээр байдаг юм бэ? Тийм зүйл хийхдээ тэд мэдэж байдаг, зүрх сэтгэлдээ зэмлэл мэдэрдэг бөгөөд үүнээс болоод заримдаа гэсгээлт, цэвэршүүлэлт туулдаг ч зүгээр л дэндүү ичгүүр сонжуургүй! Хүмүүс садар самууныг үйлдэхдээ тухайн үед юу хийж байгаагаа мэдэж байдаг боловч тэдний тачаал дэндүү их байдаг бөгөөд өөрсдийгөө хянаж чаддаггүйтэй яг адилхан. Ариун Сүнс тэднийг сахилгажуулсан ч гэсэн, энэ нь ямар ч хэрэггүй байх болно, иймээс Ариун Сүнс сахилгажуулалт оноохоо больдог. Хэрвээ тэр үед Ариун Сүнс тэднийг сахилгажуулаагүй бол, тэд ямар ч зэмлэл мэдрээгүй, махан биед нь юу ч тохиолдоогүй бол дараа нь ер нь ямар зэмлэл байх юм бэ? Үйл хэрэг дууссаны дараа ямар сахилгажуулалт байх юм бэ? Тэд хэтэрхий ичгүүр сонжуургүй, хүн чанар дутмаг бөгөөд хараагдаж, шийтгэгдвэл таарна гэдгийг л энэ нь нотолдог! Ариун Сүнс дэмий ажилладаггүй. Чи үнэнийг тун сайн мэддэг боловч хэрэгжүүлдэггүй, мөн ямар ч нүгэл үйлдэх чадвартай бол ёрын муу нэгний хамтаар шийтгэгдэх өдөр ирэхийг л хүлээхээс өөр аргагүй. Энэ бол чиний хувьд хамгийн сайн төгсгөл! Би мөс чанарын талаар ахин дахин номлолоо, энэ бол хамгийн наад захын шалгуур юм. Хүмүүст мөс чанар дутмаг бол Ариун Сүнсний сахилгажуулалтыг алдчихсан байдаг; тэд хүссэнээ хийж болох ба Бурхан тэднийг огт анхаардаггүй. Үнэхээр мөс чанартай, эрүүл ухаантай хүмүүс ямар нэг буруу зүйл хийх үедээ үүнийгээ мэднэ. Тэд мөс чанартаа бага зэрэг зэмлэл мэдэрмэгцээ тавгүйтнэ; тэд дотоод тэмцэл туулж, эцэст нь махан биеийг хаяна. Тэд Бурханыг дэндүү ноцтой эсэргүүцдэг зүйл хийх хэмжээнд очихгүй. Ариун Сүнс тэднийг хэрхэн сахилгажуулж, гэсгээх эсэхээс үл хамааран ямар нэгэн буруу зүйл хийх үедээ хүмүүст бүгдэд нь зарим нэг мэдрэмж төрнө. Тиймээс, хүмүүс одоо төрөл бүрийн үнэнийг ойлгодог ба хэрвээ тэд үүнийг хэрэгжүүлэхгүй бол энэ нь хүмүүсийн асуудал юм. Би ийм хүмүүст огт хариу үйлдэл хийдэггүй, мөн Би тэдэнд ямар ч итгэл найдвар тавьдаггүй. Чи хүссэнээ хийж болно!

Зарим хүн уулзахаараа Бурханы үгийг нэг тийш тавьж, энэ хүн, эсвэл тэр хүн ямар болох тухай үргэлж ярилцдаг. Мэдээж бага зэргийн ялган таних чадвартай

байх нь сайн, тэгснээр чи хаашаа ч явсан бай, амархан мэхлэгдэхгүй, мөн амархан зальдуулж, хууртахгүй—энэ нь ч бас хүмүүсийн эзэмших ёстой тал юм. Гэхдээ чи ганцхан энэ тал дээр төвлөрөх ёсгүй. Энэ нь аливаа зүйлийн сөрөг талтай хамаатай байдаг бөгөөд чи үргэлж бусад хүмүүс дээр харцаа тогтох ёсгүй. Чи одоо Ариун Сүнс хэрхэн ажилладаг талаар дэндүү бага мэдлэгтэй, Бурханд итгэх итгэл чинь хэтэрхий өнгөц бөгөөд чамд хэтэрхий цөөхөн эерэг зүйл байдаг. Чиний итгэдэг Нэгэн бол Бурхан бөгөөд чиний ойлгох хэрэгтэй Нэгэн бол Сатан биш, Бурхан юм. Хэрвээ чи зөвхөн Сатан хэрхэн ажилладгийг ойлгож, муу ёрын сүнснүүдийн ажилладаг бүх арга замыг мэддэг боловч Бурханы талаар ямар ч мэдлэггүй бол энэ нь ямар хэрэгтэй юм бэ? Чи өнөөдөр Бурханд итгэдэггүй гэж үү? Чиний мэдлэг яагаад эдгээр эерэг зүйлийг агуулдаггүй юм бэ? Чи оролтын эерэг талд ердөө анхаарал хандуулдаггүй, мөн үүнийг ойлгодог ч үгүй, тэгвэл итгэлээрээ чи яг юу олж авахыг хүсээд байгаа юм бэ? Чи хэрхэн эрэлхийлэх ёстойгоо мэддэггүй гэж үү? Чи сөрөг талуудын тухай ихийг мэддэг боловч оролтын эерэг талд ямар ч үр дүнд хүрдэггүй, тэгэхээр биеийн хэмжээ чинь яаж ер нь өсөж чадах юм бэ? Сатантай хийх тулааны талаар л ярьдаг чам шиг хүн хөгжин дэвших ямар хэтийн ирээдүйтэй байх юм бэ? Чиний оролт хэтэрхий хоцрогдсон байх бус уу? Ингэснээрээ чи одоогийн ажлаас юу олж авч чадах юм бэ? Чи, Бурхан одоо юу хийхийг хүсдэг, хүн хэрхэн хамтран ажиллах ёстой, тэд Бурханыг хэрхэн хайрлах ёстой, Ариун Сүнсний ажлыг хэрхэн ойлгох ёстой, өнөөдөр Бурханы хэлдэг бүх үг рүү хэрхэн орох ёстой, тэдгээрийг хэрхэн идэж ууж, туулж, ойлгох ёстой, Бурханы хүслийг хэрхэн хангаж, Бурханаар хэрхэн бүрэн байлдан дагуулагдаж, Бурханы өмнө хэрхэн захирагдах ёстой гэх зэргийг ойлгох нь одоо гол чухал юм… Эдгээр нь чиний анхаарлаа төвлөрүүлж, одоо орох ёстой зүйлс билээ. Чи ойлгож байна уу? Гагцхүү бусад хүмүүсийг ялган танихад төвлөрөх нь ямар хэрэгтэй юм бэ? Чи энд байгаа Сатаныг ялган таньж, тэнд байгаа муу ёрын сүнснүүдийг ялган таньж чадна—чи муу ёрын сүнснүүдийн талаар бүрэн дүүрэн ойлгож чаддаг боловч Бурханы ажлын талаар юу ч хэлж чаддаггүй бол тийм ялган таних чадвар Бурханы талаарх ойлголтыг чинь орлож чадах уу? Би муу ёрын сүнснүүдийн ажлын илэрхийллийн талаар урьд нь нөхөрлөсөн боловч энэ нь гол зүйл байгаагүй. Мэдээж хүмүүст бага зэргийн ялгаж таних чадвар байх ёстой бөгөөд энэ нь тэнэг зүйл хийж, Бурханы ажилд саад болохоос зайлсхийхийн тулд Бурханд үйлчилдэг хүмүүсийн эзэмших ёстой тал юм. Гэхдээ хамгийн чухал зүйл бол Бурханы ажлын талаар мэдлэгтэй байж, Бурханы хүслийг ойлгох явдал хэвээр үлддэг. Бурханы ажлын энэ үе шатны талаар дотор чинь ямар мэдлэг байгаа вэ? Чи Бурханы хийдэг зүйл юу болох, Бурханы хүсэл юу болох, чиний өөрийн дутагдал юу болох болон ямар зүйлээр зэвсэглэх ёстой тухайгаа ярьж чадах уу? Хамгийн шинэхэн оролт чинь юу болохыг чи хэлж чадах уу? Чи шинэ оролтдоо үр дүн авчирч, ойлголтод хүрч чадах ёстой. Будилсан дүр бүү үзүүл; чи өөрийн туршлага болон мэдлэгийг гүнзгийрүүлэхийн тулд шинэ оролтдоо илүү их хичээл чармайлт гаргах ёстой,

үүнээс ч илүүтэйгээр одоогийн хамгийн шинэ оролт болон туршлагажих хамгийн зөв замыг ухаарах ёстой. Түүнчлэн, шинэ ажил, шинэ оролтоор дамжуулан чи урьдын хоцрогдсон, гажуудсан хэрэгжүүлэлтээ ялган таних чадвартай болж, шинэ туршлага руу орохын тулд тэдгээрийг хаях талаар эрэлхийлэх ёстой. Эдгээр нь одоо яаралтай ойлгож, орох хэрэгтэй зүйлс чинь юм. Чи хуучин, шинэ оролтуудын хоорондох ялгаа болон харилцааг ойлгох ёстой. Хэрвээ эдгээр зүйлийг ойлгодоггүй бол чи Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлэн алхаж чадахгүй байх тул ахиц гаргах ямар ч аргагүй байх болно. Чи Бурханы үгийг хэвийн байдлаар идэж ууж, хэвийн байдлаар нөхөрлөж, тэдгээрийг ашиглан урьдын хэрэгжүүлэлтийн хоцрогдсон арга зам болон уламжлалт хуучин үзлээ өөрчлөх ёстой, ингэснээр чи шинэ хэрэгжүүлэлтэд орж, Бурханы шинэ ажилд орж болох юм. Эдгээр нь чиний биелүүлэх учиртай зүйлс билээ. Би одоо чамаас өөрийгөө яг ямар хэмжээнд байгааг л мэдэж ав гэж шаардаагүй байна; энэ бол зорилго биш. Харин ч Би чамаас үнэний хэрэгжүүлэлт болон амийн оролтын талаарх ойлголтоо ноцтойгоор авч үзэхийг шаардаж байна. Өөрийгөө мэдэх чадвар чинь жинхэнэ биеийн хэмжээг чинь төлөөлдөггүй. Хэрвээ чи Бурханы ажлыг туулж, Бурханы үгийн үнэний талаар туршлага болон ойлголттой болж чаддаг бол, мөн урьдын үзэл, алдаа мадгаа ялган таньж чаддаг бол энэ нь чиний жинхэнэ биеийн хэмжээ бөгөөд та нарын дор бүрнээ хүрэх ёстой зүйл юм.

Та нар олон нөхцөл байдалд хэрхэн хэрэгжүүлэхээ ердөө мэддэггүй ба Ариун Сүнс хэрхэн ажилладгийг бүр ч мэддэггүй. Заримдаа чи Ариун Сүнсэнд илт дуулгаваргүй зүйл хийдэг. Бурханы үгийг идэж, ууснаараа дамжуулан чи аливаа зүйлийн зарчмын талаар аль хэдийн ухаарсан байдаг тул дотор чинь зэмлэл болон түгшүүрийн мэдрэмж төрдөг; мэдээж энэ нь зарим үнэнийг мэдсэн нөхцөлд л хүний мэдрэх мэдрэмж юм. Хэрвээ хүмүүс Бурханы өнөөдрийн үгэнд нийцүүлэн хамтран ажилладаггүй, эсвэл хэрэгжүүлдэггүй бол Ариун Сүнсний ажилд саад болж байгаа бөгөөд тэд дотроо түгшүүр мэдрэх нь гарцаагүй. Чи тодорхой нэг талын зарчмыг ойлгодог боловч үүний дагуу хэрэгжүүлдэггүй гэе, тэгвэл чи дотроо зэмлэсэн мэдрэмжийг мэдэрнэ. Хэрвээ чи зарчмыг ойлгодоггүй, энэ талын үнэнийг огт мэддэггүй бол энэ асуудал дээр зэмлэсэн мэдрэмжийг заавал мэдрээд байхгүй. Ариун Сүнсний зэмлэл үргэлж нөхцөлтэй байдаг. Чи залбираагүй, Ариун Сүнстэй хамтран ажиллаагүй учраас ажлыг саатуулчихлаа гэж чи боддог. Үнэн хэрэгтээ үүнийг саатуулж чадахгүй. Ариун Сүнс өөр хэн нэгний сэтгэлийг хөдөлгөнө; Ариун Сүнсний ажил хэнээр ч хязгаарлагддаггүй. Бурханы урмыг хугаллаа гэж чамд санагддаг ба энэ нь мөс чанарт чинь байх ёстой мэдрэмж юм. Үнэнийг олж авч чадах уу, үгүй юу гэдэг чинь чиний л хэрэг бөгөөд Бурхантай хамаагүй. Заримдаа мөс чанар чинь буруушаалт мэдэрдэг боловч энэ нь Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт биш, Ариун Сүнсний зэмлэл ч биш. Харин ч энэ нь хүний мөс чанар доторх мэдрэмж юм. Хэрвээ чи Бурханы нэр, Бурханы гэрчлэл, эсвэл Бурханы ажилтай холбоотой асуудал дээр дур зоргоороо үйлддэг бол Бурхан чамайг зүгээр орхихгүй. Гэхдээ үүнд хязгаар байдаг—ердийн, жаахан асуудлууд дээр Бурхан

чамайг зовоохгүй. Тэр чамайг үл тооно. Хэрвээ чи зарчмуудыг зөрчиж, Бурханы ажлыг үймүүлж, нураавал Тэрээр уур хилэнгээ чам дээр гаргах ба чамайг яасан ч зүгээр орхихгүй. Чиний гаргадаг зарим алдаа нь хүний амьдралын замналд зайлшгүй тохиолддог. Жишээлбэл, чи мантуугаа зөв жигнээгүй бөгөөд энэ нь Бурхан чамайг сахилгажуулж байгаа хэрэг гэж хэлдэг—энэ бол хэлэхэд туйлын үндэслэлгүй зүйл. Бурханд итгэж эхлэхээс чинь өмнө иймэрхүү зүйл олон удаа тохиолдож байгаагүй гэж үү? Чамд энэ нь Ариун Сүнсний сахилгажуулалт шиг санагддаг боловч үнэн хэрэгтээ тийм биш (зарим онцгой нөхцөл байдлыг үл оролцуулан), учир нь энэхүү ажил тэр чигтээ Ариун Сүнснээс ирдэггүй, харин ч хүний мэдрэмжээс гардаг. Гэхдээ, итгэлтэй хүмүүсийн хувьд ингэж бодох нь хэвийн зүйл. Чи Бурханд итгээгүй байхдаа ингэж боддог байсан байж таарахгүй. Бурханд итгэж эхэлмэгцээ чи эдгээр зүйлийг эргэцүүлэхэд илүү их цаг зарцуулж эхэлдэг тул аяндаа ингэж бодож эхэлдэг. Энэ нь хэвийн хүмүүсийн бодлоос урган гардаг бөгөөд тэдний сэтгэхүйтэй хамаатай байдаг. Гэхдээ ийм бодол нь Ариун Сүнсний ажлын цар хүрээнд багтдаг зүйл биш гэдгийг Би чамд хэлье. Энэ нь, Ариун Сүнс хүмүүст бодлоор нь дамжуулан хэвийн хариу үйлдэл өгч буйн жишээ юм; гэхдээ энэ хариу үйлдэл нь Ариун Сүнсний ажил биш гэдгийг чи ойлгох ёстой. Ийм төрлийн “мэдлэгтэй” байх нь чамд Ариун Сүнсний ажил байгаа гэдгийг нотолдоггүй. Чиний мэдлэг Ариун Сүнсний гэгээрлээс гарч ирдэггүй, тэр ч бүү хэл энэ нь Ариун Сүнсний ажил биш. Энэ нь ердөө хүмүүсийн хэвийн бодлын үр дүн бөгөөд энэ нь Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлттэй ямар ч холбоогүй—эдгээр нь эрс ялгаатай зүйл үзэгдэл юм. Хүний ийм хэвийн бодол нь тэр чигтээ Ариун Сүнснээс гардаггүй. Ариун Сүнс хүмүүсийг гэгээрүүлэхээр ажиллах үедээ тэдэнд ерөнхийдөө Бурханы ажлын тухай, өөрсдийнх нь жинхэнэ оролт, жинхэнэ байр байдлын тухай мэдлэг өгдөг. Тэр бас, Бурханы яаралтай санаа зорилго болон өнөөдөр хүнд тавьдаг Бурханы шаардлагыг тэдэнд ойлгуулдаг, ингэснээр тэд хавчлага, саад бэрхшээлтэй тулгарсан ч гэсэн Бурханыг хангалуун байлган, хайрлахын тулд бүхнийг золиосолж, цусаа урсган, амиа өгөх байсан ч гэсэн Бурханы төлөө гэрчлэлд зогсож, харамсахгүйгээр ийнхүү хийх шийдвэртэй болдог. Хэрвээ чамд ийм шийдвэр байгаа бол Ариун Сүнс сэтгэлийг чинь хөдөлгөдөг ба чамд Ариун Сүнсний ажил байгаа гэсэн үг—гэхдээ урсан өнгөрөх хором бүрд чамд тийм сэтгэл хөдлөл байдаггүй гэдгийг мэдэж ав. Заримдаа цуглаан дээр Бурханы үгийг идэж, уух үед сэтгэл чинь туйлын их хөдөлж, зоригждог. Бусад хүмүүс Бурханы үгийн талаарх өөрсдийн туршлага, ойлголтыг нөхөрлөх үед тун шинэ, шинэлэг санагдаж, зүрх сэтгэл чинь тов тодорхой, гэгээлэг байдаг. Энэ нь бүгд Ариун Сүнсний ажил юм. Хэрвээ чи удирдагч бөгөөд ажиллахаар чуулган руу явах үед чинь Ариун Сүнс хосгүй гэгээрэл, гэрэлтүүлэлт өгч, чуулган дотор оршдог асуудлуудыг нэгд нэггүй ойлгуулж, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд үнэний талаар хэрхэн нөхөрлөхөө мэдэх боломж олгон, чамайг ажилдаа тун үнэнч, хариуцлагатай, нухацтай болгодог бол энэ бүхэн нь Ариун Сүнсний ажил мөн.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 2

Өнгөрсөн үед хүмүүс цаг үргэлж Бурхантай хамт байж, сүнсэн дотор амьдрахын тулд өөрсдийгөө сургадаг байсан. Өнөөдрийн хэрэгжүүлэлттэй харьцуулбал тэр нь сүнслэг сургуулилтын энгийн хэлбэр юм; энэ бол хүмүүс амийн зөв замд орохын өмнөх хамгийн өнгөц, энгийн хэрэгжүүлэлтийн зам бөгөөд энэ нь хүмүүсийн итгэл дэх хэрэгжүүлэлтийн хамгийн эхний үе шатыг бүрдүүлдэг. Хэрвээ хүмүүс амьдралдаа ийм төрлийн хэрэгжүүлэлтэд үргэлж түшиглэдэг бол тэд ихээхэн сэтгэл хөдлөлтэй байж, алдаа гаргах боломжтой бөгөөд амийн жинхэнэ туршлагад орж чадахгүй байх болно; тэд зүрх сэтгэлээ хэвийн байдлаар Бурханд ойртох чадвартай байлгаж, Бурхантай хамт байгаадаа үргэлж асар их баяр хөөртэй байж, ердөө сүнсээ л дасгалжуулж чадах болно. Тэд Бурхантай ойр дотно байх жаахан ертөнцөд хязгаарлагдаж, хамгийн гүнд юу байгааг ухаарах чадваргүй байх болно. Зөвхөн эдгээр хил хязгаар дотор амьдардаг хүмүүс ямар ч агуу ахиц гаргах чадваргүй байдаг. Тэд хэдийд ч, “Аа! Эзэн Есүс минь. Амен!” хэмээн хашхирч болзошгүй байдаг. Бараг өдөр болгон ийм байдаг. Энэ бол өнгөрсөн үеийн хэрэгжүүлэлт, хором бүрд сүнсэн дотор амьдрах тухай хэрэгжүүлэлт юм. Энэ нь бүдүүлэг биш гэж үү? Өнөөдөр, Бурханы үгийг тунгаан бодох цаг болоход чи зүгээр л Бурханы үгийг тунгаан бодоход анхаарлаа төвлөрүүл; үнэнийг хэрэгжүүлэх цаг болоход үнэнийг хэрэгжүүлэхэд л анхаарлаа төвлөрүүл; үүргээ биелүүлэх цаг ирэхэд зүгээр л үүргээ биелүүл. Ингэж хэрэгжүүлэх нь үнэндээ нэлээд чөлөөтэй байдаг, энэ нь чамайг чөлөөлдөг. Энэ нь шашны хөгшчүүлийн залбирч, талархал хэлдэгтэй адилхан биш. Мэдээж урьд нь Бурханд итгэдэг хүмүүс ингэж хэрэгжүүлдэг байсан, гэхдээ үргэлж ийм байдлаар хэрэгжүүлэх нь хэтэрхий хоцрогдмол юм. Бурханы ажил одоо хамгийн өндөр түвшинд байгаа; өнөөдөр “Бурханыг бодит амьдралд авчрах” тухай ярьдаг нь хэрэгжүүлэлтийн хамгийн чухал тал мөн. Энэ нь бодит амьдралдаа хүмүүсийн эзэмших ёстой хэвийн хүн чанар бөгөөд хэвийн хүн чанартаа хүмүүсийн эзэмших ёстой зүйл нь өнөөдөр Бурханы хэлдэг бүх үг билээ. Бурханы үгийг бодит амьдралд авчрах нь “Бурханыг бодит амьдралд авчрах” гэдгийн бодитой утга учир юм. Өнөөдөр хүмүүс үндсэндээ өөрсдийгөө дараах зүйлсээр зэвсэглэх ёстой: Нэг талаар, тэд хэв чанараа сайжруулж, боловсролтой болж, уншиж ойлгох чадвараа сайжруулах ёстой; нөгөө талаар, тэд хэвийн хүний амьдралаар амьдрах ёстой. Чи энэ дэлхийгээс Бурханы өмнө дөнгөж сая эргэн ирсэн; чи эхлээд зүрх сэтгэлээ Бурханы өмнө тайван байлгаж сурах ёстой. Энэ бол хэрэгжүүлэлтийн эхлэл бөгөөд бас амь зан чанарын өөрчлөлтөд хүрэх эхний алхам юм. Зарим хүн хэрэгжүүлэлтдээ харьцангуй дадамгай байдаг; тэд ажиллах зуураа үнэнийг тунгаан бодож, бодит байдал дээр өөрсдийн ойлгох ёстой үнэн болон хэрэгжүүлэлтийн зарчмуудыг ойлгохоор оролддог. Нэг талаар, чи хэвийн хүний амьдралтай байх ёстой, нөгөө талаар, үнэнд орох оролт байх ёстой. Энэ бүхэн нь бодит амьдралын хамгийн шилдэг хэрэгжүүлэлтийг бүрдүүлдэг.

Бурханыг бодит амьдралдаа авчрах нь үндсэндээ, хэвийн хүн чанарын дотор Бурханд шүтэн мөргөж, Бурханы тухай мэдэхээр эрж хайж, Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхийг хүмүүсээс шаарддаг. Тэд ямар нэг юм хийх болгондоо заавал Бурханд залбирч, залбираагүй бол Бурханд өртэй мэт санагдах албагүй. Өнөөдрийн хэрэгжүүлэлт тийм биш; энэ нь үнэхээр тайван агаад амархан! Энэ нь хүмүүсээр хоосон сургаал баримтлуулах явдал биш. Харин ч, хүн нэг бүр өөрсдийн биеийн хэмжээний дагуу үйлдэх ёстой: Хэрвээ гэр бүлийнхэн чинь Бурханд итгэдэггүй бол тэднийг үл итгэгчид гэж үз, хэрвээ итгэдэг бол итгэгчид гэж ханд. Хайр, тэвчээрийг бус, харин мэргэн ухааныг хэрэгжүүл. Зарим хүн хүнсний ногоо худалдаж авахаар явдаг ба алхах зуураа тэд: “Өө Бурхан минь! Өнөөдөр Та надаар ямар ногоо авхуулах вэ? Би Таны тусламжийг гуйж байна. Бүх зүйл дээр Өөрийг нь алдаршуулж, гэрчлэл хийхийг Бурхан биднээс шаарддаг тул худалдагч надад муудсан юм өгсөн ч гэсэн би Бурханд талархсаар байх болно—би тэвчинэ. Бурханд итгэдэг хүмүүс бид ногоонуудаас шилж, сонгож болохгүй” гэж бувтнадаг. Ингэх нь гэрчлэл хийж байгаа хэрэг гэж тэд боддог бөгөөд үр дүнд нь, муудсан хэсэг ногоо худалдан авахад мөнгөө зарцуулдаг ч мөн л залбирч, “Өө Бурхан минь! Та л зөвшөөрч байгаа цагт би энэ муудсан ногоог иднэ” хэмээн хэлдэг. Ийм хэрэгжүүлэлт утгагүй биш гэж үү? Энэ нь хоосон сургаалыг дагаж байгаа хэрэг биш гэж үү? Өмнө нь, хүмүүс цаг үргэлж сүнсэн дотор амьдрах дадлага хийж байсан бөгөөд энэ нь Нигүүлслийн эрин үед хийгдсэн ажилтай хамаатай байв. Сүсэг бишрэл, даруу төлөв байдал, хайр, тэвчээр, бүх зүйлд талархах—эдгээр нь Нигүүлслийн эрин үе дэх итгэгч бүрээс шаардаж байсан зүйл юм. Тэр үед хүмүүс бүх зүйл дээр Бурханд залбирдаг байсан; тэд хувцас худалдаж авахдаа, цуглааны талаар мэдэгдэл авах үедээ ч гэсэн залбирч, “Өө Бурхан минь! Та намайг явахыг зөвшөөрөх үү, үгүй юү? Хэрвээ явахыг зөвшөөрвөл Та надад өөгүй тэгш зам бэлдээч. Хэрвээ Та явахыг минь зөвшөөрөхгүй бол намайг бүдрүүлж, унагаач” гэдэг байлаа. Залбирангаа тэд Бурханаас гуйдаг ба залбирсны дараа тавгүй санагдвал явдаггүй байв. Зарим эгч, цуглааны дараа гэртээ хариад үл итгэгч нөхөртөө зодуулж магад гэж айгаад, залбирах үед нь тавгүй санагдсанаас болж цуглаанд явдаггүй байлаа. Тэд үүнийг Бурханы хүсэл гэж итгэдэг ч үнэн хэрэгтээ хэрвээ явсан бол юу ч тохиолдохгүй байх байсан юм. Үр дүнд нь тэд цуглаанд оролцож чадаагүй. Энэ бүхэн хүмүүсийн мэдлэггүй байдлаас болдог. Ийм байдлаар хэрэгжүүлдэг хүмүүс мэдрэмжээрээ амьдардаг. Ийм арга замаар хэрэгжүүлэх нь алдаатай, утгагүй бөгөөд тодорхой бус байдлаар будагдсан байдаг. Үүнд тэдний хувийн мэдрэмж ба бодол дэндүү их байдаг. Хэрвээ чамд цуглааны тухай хэлсэн бол яв; Бурханд залбирах хэрэггүй. Энэ нь энгийн биш гэж үү? Хэрвээ өнөөдөр чи хувцас хунар авах хэрэгтэй бол яг одоо гараад ав. “Өө Бурхан минь! Та намайг явуулах уу, үгүй юү? Намайг явсан хойгуур ах, эгч нарын нэг нь ирж таарвал яах вэ?” хэмээн Бурханд бүү залбир. Аль нэг ах, эгч ирж магадгүй гэж айгаад чи явдаггүй, гэтэл үр дүнд нь, орой болж, нэг ч хүн ирээгүй. Нигүүлслийн эрин үед ч

гэсэн ийм байдлаар хэрэгжүүлэх нь эндүү ташаа, буруу байсан. Тиймээс хэрвээ хүмүүс өнгөрсөн цаг үеийнх шигээ хэрэгжүүлбэл тэдний аминд ямар ч өөрчлөлт гарахгүй. Тэд ердөө хүлцэнгүй байх бөгөөд ялган салгахад ямар ч анхаарал хандуулахгүй, сохроор дуулгавартай дагаж, тэвчихээс өөрийг хийхгүй. Тухайн үед хүмүүс Бурханыг алдаршуулахад төвлөрдөг байсан—гэхдээ Бурхан тэднээс ямар ч алдрыг олж аваагүй, учир нь тэд ямар ч бодитой зүйлийг амьдран харуулаагүй билээ. Тэд ердөө хувийн үзлээрээ биеэ барьж, өөрсдийгөө хязгаарласан ба олон жилийн хэрэгжүүлэлт ч тэдний аминд ямар нэг өөрчлөлт авчраагүй; тэд зөвхөн тэвчиж, даруухан байж, хайрлаж, уучлахыг л мэддэг байсан ба Ариун Сүнсний өчүүхэн төдий ч гэгээрэл байгаагүй юм. Тийм маягаар хүмүүс яаж Бурханыг мэдэж чадах юм бэ? Тэд яаж ер нь Бурханыг алдаршуулж чадах юм бэ?

Хүмүүс Бурханыг бодит амьдралдаа, хэвийн хүний амьдралдаа авчирвал л Бурханд итгэх итгэлийн зөв замд орж чадна. Өнөөдөр Бурханы үг та нарыг хөтөлдөг; өнгөрсөн үеийнх шиг эрж хайж, тэмтчих хэрэггүй. Бурханы үгийн дагуу хэрэгжүүлж, Миний илчилсэн байдлын дагуу өөрийгөө шалгаж, хэмжих үедээ чи өөрчлөгдөж чадна. Энэ нь хоосон сургаал биш, харин хүнээс Бурханы шаарддаг зүйл юм. Өнөөдөр Би чамд юмсын үнэн мөнийг хэлж өгье: Миний үгийн дагуу үйлдэхэд л санаа тавь. Чамаас шаардах шаардлага минь хэвийн хүний хэрэгцээний дагуу байдаг. Би чамд Өөрийн үгийг аль хэдийн хэлсэн; хэрвээ чи гагцхүү тэдгээрийг хэрэгжүүлэхэд төвлөрөх юм бол Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадна. Өнөөдөр бол Бурханы үгэн дотор амьдрах цаг үе: Бурханы үг бүгдийг тайлбарласан, бүх зүйл тодорхой болсон ба Бурханы үгээр амьдарч байгаа цагт чи бүрэн эрх чөлөөтэй, чөлөөлөгдсөн амьдралаар амьдарна. Өмнө нь, Бурханыг бодит амьдралдаа авчрах үедээ хүмүүс хэтэрхий их хоосон сургаал, зан үйлийг хэрэгжүүлж, туулсан; ялихгүй хэрэг явдал дээр ч тэд залбирч, эрж хайн, Бурханы тодорхой өгүүлсэн үгийг хойш тавьж, уншилгүй үл ойшоодог байсан. Харин ч тэд эрж хайхад бүх хичээл чармайлтаа зориулаад—үр дүнд нь ямар ч үр нөлөө гараагүй. Жишээлбэл, хоол хүнс, хувцасны асуудлыг авч үзье: Залбирах үедээ чи эдгээр хэрэг явдлыг Бурханы гарт тавьж, энэ бүхнийг чамд зориулан цэгцэлж өгөхийг Бурханаас гуйдаг. Бурхан ийм үг сонсоод: “Би тийм аар саар зүйлд санаа тавих хэрэгтэй гэж үү? Чамд зориулан Миний бүтээсэн хэвийн хүн чанар, эрүүл ухаан хаачсан юм бэ?” гэдэг. Заримдаа хүн үйлдлээрээ алдаа гаргадаг; тэгээд тэд Бурханд халдсан гэж бодоод, биеэ барьдаг. Зарим хүний байр байдал тун сайн байдаг ч жаахан зүйл буруу хийх үедээ Бурхан өөрсдийг нь гэсгээж байна гэж итгэдэг. Үнэндээ энэ нь Бурханы хийсэн зүйл биш, харин хүмүүсийн өөрсдийнх нь оюун ухааны нөлөө юм. Заримдаа хэрхэн туршлагажиж байгаад чинь ямар ч буруу байдаггүй боловч бусад хүмүүс чамайг зөв туршлагажихгүй байна гэж хэлдэг тул чи урхидуулж, дотроо сөрөг, харанхуй болдог. Ихэнхдээ хүмүүс ийм маягаар идэвхгүй байх үедээ Бурханаар гэсгээгдэж байна гэдэгтээ итгэдэг боловч Бурхан: “Би чам дээр ямар ч гэсгээлтийн ажил хийгээгүй; чи яаж Намайг ингэж буруутгаж

чадаж байна вэ?” гэдэг. Хүмүүс дэндүү амархан сөрөг болдог. Тэд бас ихэнхдээ хэт мэдрэмтгий байдаг бөгөөд Бурханы талаар удаа дараа гомдоллодог. Бурхан чамаас тийм маягаар зовохыг шаарддаггүй ч чи өөрийгөө тийм байдалд оруулдаг. Ингэж зовох нь ямар ч үнэ цэнгүй. Хүмүүс Бурханы хийсэн ажлыг мэддэггүй, мөн олон зүйл дээр мэдлэггүй байж, тодорхой харж чаддаггүй тул өөрсдийн үзэл, төсөөлөлд урхидуулж, бүр ч гүн орооцолддог. Бүх зүйл, бүх хэрэг явдал Бурханы гарт байдаг гэж зарим хүн хэлдэг—тэгвэл хүмүүсийг сөрөг байхад Бурхан мэдэхгүй гэж үү? Мэдээж Бурхан мэддэг. Чамайг хүний үзэлд урхидуулсан байх үед Ариун Сүнс чам дээр ажиллах ямар ч аргагүй байдаг. Зарим хүн олон удаа сөрөг байдалд автдаг боловч Би Өөрийн ажлыг үргэлжлүүлсээр байдаг. Чи сөрөг ч бай, эерэг ч бай Би чамаар хязгаарлуулахгүй—харин Миний хэлдэг олон үг болон Миний хийдэг асар их хэмжээний ажил хүмүүсийн байр байдлын дагуу, өөр хоорондоо нягт холбоотой байдаг гэдгийг чи мэдэх ёстой. Чамайг сөрөг байх үед энэ нь Ариун Сүнсний ажилд саад болдоггүй. Гэсгээлт болон үхлийн шалгалтын хугацаанд хүмүүс бүгд сөрөг байдалд автдаг боловч энэ нь Миний ажилд саад болоогүй. Чамайг сөрөг байх үед Ариун Сүнс бусдад хийх хэрэгтэй зүйлийг үргэлжлүүлэн хийсээр байсан. Чи нэг сарын турш эрэлхийлэхээ больж болох ч Би үргэлжлүүлэн ажилладаг—чи одоо, эсвэл ирээдүйд юу ч хийсэн бай, энэ нь Ариун Сүнсний ажлыг зогсоож чадахгүй. Зарим сөрөг байдал хүний сул талаас үүсдэг; хүмүүс Бурханы шаардлагуудад нийцэж, тэдгээрийг ухаарч үнэхээр чадахгүй гэж бодох үедээ сөрөг болдог. Жишээлбэл, гэсгээлтийн цаг үеийн Бурханы үг нь, гэсгээлтийн үеэр Бурханыг тодорхой түвшинд хайрлах талаар ярьсан боловч хүмүүс өөрсдийгөө чадахгүй гэж бодсон. Тэгээд махан бие нь Сатанаар маш гүн завхруулагдаж, хэв чанар нь маш дорд байгаад тэд нэн харамсаж, шаналсан. Мөн ийм орчинд төрсөн нь үнэхээр хөөрхийлөлтэй юм гэж тэдэнд санагдсан. Бурханд итгэж, Бурханыг мэдэхэд хэтэрхий оройтсон ба төгс болгуулах ямар ч үнэ цэнгүй гэж зарим хүнд санагдсан. Энэ бүхэн нь хэвийн хүний байдал юм.

Хүний махан бие Сатаных, энэ нь дуулгаваргүй зан чанараар дүүрэн, харамсмаар бузар заваан бөгөөд бохир зүйл юм. Хүмүүс махан биеийн зугаа цэнгэлд маш их шунадаг, махан биеийн хэтэрхий олон илэрхийлэл байдаг ба иймээс Бурхан махан биеийг тодорхой хэмжээгээр зэвүүцдэг. Хүмүүс Сатаны бузар заваан, завхарсан зүйлсийг орхих үедээ Бурханы авралыг олж авдаг. Гэвч хэрвээ тэд бузар заваан болон завхралаас өөрсдийгөө салгаж чадахгүй хэвээр үлдвэл Сатаны эзэмшил дор байсаар байх болно. Хүмүүсийн хуйвалдаан, хуурмаг зан болон шударга бус байдал нь Сатаны зүйлс юм. Бурхан чамайг аварч байгаа нь чамайг Сатаны эдгээр зүйлээс салгахын төлөө байдаг. Бурханы ажил буруу байж болохгүй, энэ нь бүгд хүмүүсийг харанхуйгаас аврахын төлөө байдаг. Чи тодорхой хэмжээгээр итгэж, махан биеийн завхралаас өөрийгөө салгаж, энэ завхралд дөнгөлөгдөхөө больж чадах үедээ аврагдчихсан байх бус уу? Чи Сатаны эзэмшил дор амьдарч байх үедээ Бурханыг илэрхийлэх чадваргүй, бузар заваан

зүйл байх бөгөөд Бурханы өв залгамжлалыг хүлээн авахгүй. Цэвэрлэгдэж, төгс болгуулмагцаа чи ариун байх болно, мөн хэвийн хүн байх ба Бурханаар ерөөгдөж, таашаагдана. Өнөөдөр Бурханы хийдэг ажил бол аврал юм, түүнчлэн энэ нь шүүлт, гэсгээлт, хараал юм. Үүнд хэд хэдэн тал бий. Бурханы айлдварууд шүүлт, гэсгээлт, мөн түүнчлэн хараал агуулдаг гэдгийг та нар бүгд хардаг. Би үр дүнд хүрэхийн тулд, хүмүүст өөрсдийг нь мэдүүлэхийн тулд ярьдаг болохоос хүмүүсийг үхэлд хүргэхийн төлөө ярьдаггүй. Миний зүрх сэтгэл та нарын төлөө байдаг. Үг хэлэх нь Миний ажилладаг арга барилуудын нэг; Би үгээр дамжуулан Бурханы зан чанарыг илэрхийлж, Бурханы хүслийг чамд ойлгуулдаг. Махан бие чинь үхэж болох ч чамд сүнс болон сэтгэл бий. Хэрвээ хүмүүст зөвхөн махан бие байсан бол Бурханд итгэх итгэл нь ямар ч утгагүй байх байсан, мөн Миний хийсэн энэ бүх ажил ч ямар ч утгагүй байх байлаа. Өнөөдөр Би энийг яриад, дараа нь тэрийг ярьдаг, нэг хоромд Би хүмүүсийг туйлын их үзэн ядаад, дараагийн хоромд дээд зэргээр хайрладаг; чиний зан чанарт өөрчлөлт гаргаж, Бурханы ажлын тухай үзлийг чинь өөрчлөхийн тулд Би энэ бүхнийг хийдэг.

Эцсийн өдрүүд ирж, дэлхий даяарх улс орнууд үймээн самуунтай байна. Улс төрийн эмх замбараагүй байдал, өлсгөлөн, тахал, үер, ган гачиг хаа сайгүй үзэгдэж, хүний ертөнцөд гай зовлон тохиолдож байгаа бөгөөд Тэнгэр ч бас гай гамшиг илгээсэн. Эдгээр нь эцсийн өдрүүдийн шинж тэмдэг юм. Гэхдээ хүмүүст энэ нь зугаа цэнгэлийн нүд гялбам ертөнц шиг санагддаг; энэ нь улам бүр тийм болсоор байгаа бөгөөд хүмүүсийн сэтгэл бүхэлдээ үүнд татагдаж, олон хүн урхидуулаад, өөрсдийгөө үүнээс чөлөөлж чаддаггүй; заль мэх гаргаж, хар шид хийдэг хүмүүст асар олон тооны хүн мэхлэгдэнэ. Хэрвээ чи ахиц гаргахаар мэрийхгүй, туйлын хүслэнгүй, үнэн замд суурилаагүй бол энэхүү нүгэлт давлагаанд хамагдан одно. Хятад бол бүх улс орноос хамгийн хоцрогдмол бөгөөд агуу улаан лууны цагариглан хэвтдэг газар юм, энд хуурамч шүтээн шүтэж, хар шид хийдэг хамгийн олон хүн, мөн хамгийн олон сүм байдаг ба энэ нь бузар чөтгөрийн оршин суудаг газар билээ. Чи үүнээс төрсөн, үүний боловсролыг эзэмшиж, нөлөөнд нь автсан; үүгээр завхруулагдаж, тамлуулсан, гэхдээ чамайг сэрээсний дараа чи үүнийг хаяж, Бурханаар бүрэн авахуулдаг. Энэ бол Бурханы алдар, иймээс ажлын энэ үе шат асар их ач холбогдолтой. Бурхан ийм агуу далайцтай ажил хийж, маш олон үг хэлсэн бөгөөд эцэст нь та нарыг бүрмөсөн олж авна—энэ бол Бурханы удирдлагын ажлын нэг хэсэг бөгөөд та нар бол Сатантай хийж буй Бурханы тулааны “ялалтын олз” юм. Та нар үнэнийг хэдий чинээ их ойлгоно, чуулганы амьдрал чинь төдий чинээ сайжирч, агуу улаан лууг төдий чинээ буулгаж авна. Эдгээр нь бүгд сүнсний ертөнцийн хэрэг явдлууд юм—тэдгээр нь сүнсний ертөнцийн тулаан бөгөөд Бурхан ялалт авчрах үед Сатан шившиглэгдэж, нуран унана. Бурханы ажлын энэ үе шат үлэмж их ач холбогдолтой. Бурхан тийм далайцтай ажил хийж, энэ бүлэг хүмүүсийг бүрмөсөн авардаг болохоор чи Сатаны нөлөөнөөс зугтаж, ариун газарт амьдарч, Бурханы гэрэлд амьдарч, гэрлийн манлайлал болон удирдамжтай байж чаддаг.

Мөн амьд байгаа чинь утга учиртай байдаг. Та нарын идэж, өмсөж байгаа зүйл үл итгэгчдийнхээс өөр; та нар Бурханы үгийг эдэлж, утга учиртай амьдралаар амьдардаг—тэгвэл тэд юу эдэлдэг вэ? Тэд “өвөг дээдсийнхээ өв хөрөнгийг” болон “үндэсний сэтгэлийг” л эдэлдэг. Тэдэнд хүн чанарын өчүүхэн ч ул мөр байдаггүй! Та нарын хувцас, үг, үйлдэл бүгд тэднийхээс өөр. Эцсийн эцэст та нар бузар заваанаас бүрмөсөн зайлж, Сатаны уруу таталтад хууртахаа больж, Бурханы өдөр тутмын хангалтыг олж авна. Та нар үргэлж болгоомжтой байх ёстой. Хэдий бузар газарт амьдардаг боловч та нар бузар заваанаар бохирдоогүй ба Бурханы хажууд амьдарч, Түүний агуу хамгаалалтыг хүлээн авч чадна. Бурхан та нарыг энэхүү шар газар нутагт байгаа бүх хүний дундаас сонгосон. Та нар хамгийн ерөөгдсөн хүмүүс биш гэж үү? Бүтээгдсэн зүйл болохын хувьд чи мэдээж Бурханд шүтэн мөргөж, утга учиртай амьдралыг эрэлхийлэх ёстой. Хэрвээ чи Бурханд шүтэн мөргөхгүй, харин бузар махан биед амьдарвал зүгээр л хүний өмсгөлтэй араатан биш гэж үү? Хүн болохын хувьд чи Бурханы төлөө өөрийгөө зарцуулж, бүх зовлонг тэвчих ёстой! Өнөөдөр өөрт чинь учирсан жаахан зовлонг чи баяртайгаар, итгэлтэйгээр хүлээн авч, Иов, Петр хоёр шиг утга учиртай амьдралаар амьдрах ёстой. Энэ дэлхий ертөнцөд хүн диаволын хувцсыг өмсөж, диаволын өгсөн хоолыг идэж, диаволын хяналтан дор ажиллаж, үйлчилж, түүний бузар заваанд нухлагддаг. Хэрвээ чи амьдралын утга учрыг ухаардаггүй, эсвэл үнэн замыг олж авдаггүй бол ингэж амьдрахад ямар ач холбогдол байх юм бэ? Та нар бол зөв замыг эрэлхийлдэг, ахиц дэвшлийг эрж хайдаг хүмүүс юм. Та нар бол агуу улаан лууны улс оронд өндийн боссон, Бурханы зөв шударга гэж нэрлэдэг хүмүүс билээ. Энэ нь хамгийн утга учиртай амьдрал биш гэж үү?

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ 1

Нигүүлслийн эрин үед Иохан Есүст зориулан зам тавьсан. Иохан Бурханы Өөрийн ажлыг хийж чадаагүй, харин ердөө хүний үүргийг л биелүүлсэн юм. Хэдийгээр Иохан Эзэний анхдагч байсан ч Бурханыг төлөөлж чадаагүй; тэр ердөө Ариун Сүнсний ашигладаг хүн байлаа. Есүсийг баптисм хүртсэний дараа Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт буужээ. Дараа нь Тэрээр ажлаа эхэлсэн, өөрөөр хэлбэл, Христийн үйлчлэлийг гүйцэтгэж эхэлсэн юм. Тийм учраас Тэр Бурханы ялгамж чанарыг авсан, учир нь Тэр Бурханаас ирсэн билээ. Үүнээс өмнө Түүний итгэл ямар байсан нь хамаагүй—заримдаа сул дорой, заримдаа хүчтэй байсан байж болох ч—бүгд Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхээс өмнөх хэвийн хүний амьдралд нь харьяалагдаж байв. Түүнийг баптисм хүртсэний (өөрөөр хэлбэл, тосолсны) дараа Бурханы хүч чадал, алдар суу нэн даруй Түүнтэй хамт байсан тул Тэрээр үйлчлэлээ гүйцэтгэж эхэлсэн юм. Тэрээр тэмдэг, гайхамшиг бүтээж, ид шид үзүүлж чаддаг байсан бөгөөд хүч чадал, эрх мэдэлтэй байлаа, учир нь Тэр Бурханы

Өөрийн өмнөөс шууд ажиллаж байсан билээ; Тэрээр Сүнсний өмнөөс ажил хийж, Сүнсний дуу хоолойг илэрхийлж байв. Тиймээс Тэр бол Бурхан Өөрөө байсан юм; энэ нь маргаангүй. Иохан бол Ариун Сүнсний ашигладаг хүн байсан. Тэр Бурханыг төлөөлж чадаагүй, түүний хувьд Бурханыг төлөөлөх боломж ч байгаагүй. Хэрвээ тэр ингэхийг хүссэн бол Ариун Сүнс зөвшөөрөхгүй байх байлаа, учир нь Бурханы Өөрийн биелүүлэхээр зорьсон ажлыг тэр хийх чадваргүй байсан юм. Магадгүй түүнд хүний хүсэл ихээхэн байсан, эсвэл ямар нэгэн гажуудал байсан байх; ямар ч тохиолдолд тэр Бурханыг шууд төлөөлж чадахгүй байв. Түүний алдаа, утгагүй явдал зөвхөн түүнийг төлөөлж байсан боловч ажил нь харин Ариун Сүнсийг төлөөлж байлаа. Гэвч түүний бүх зүйл Бурханыг төлөөлж байсан гэж хэлж болохгүй. Түүний гажуудал, алдаа мадаг нь ч бас Бурханыг төлөөлж чадсан гэж үү? Хүнийг илэрхийлэхдээ алдаа мадагтай байх нь хэвийн зүйл боловч Бурханыг төлөөлөхдөө гажуудалтай бол Бурханыг гутаасан хэрэг болох биш үү? Тэр нь Ариун Сүнсний эсрэг доромжлол байх бус уу? Бусдаар өргөмжлүүлдэг байсан ч гэсэн тухайн хүнийг Бурханы байр сууринд зогсохыг Ариун Сүнс хялбархан зөвшөөрдөггүй. Хэрвээ тэр Бурхан л биш бол эцэст нь бат зогсож чадахгүй. Ариун Сүнс, Бурханыг хүссэнээрээ төлөөлөхийг хүнд зөвшөөрдөггүй! Жишээ нь, Ариун Сүнс Иоханд гэрчлэл хийсэн бөгөөд Есүст зориулан зам тавих нэгэн болохыг нь ч бас илчилсэн боловч түүн дээр Ариун Сүнсний хийсэн ажил нэлээд хянамгай байв. Есүсийн төлөө зам тавигч байж, Түүнд зориулсан замыг бэлдэхийг л Иоханаас хүссэн юм. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнс зам тавих ажлыг нь л дэмжиж, тийм ажил хийхийг л түүнд зөвшөөрсөн—өөр ажил хийхийг түүнд зөвшөөрөөгүй. Иохан Елиаг төлөөлсөн бөгөөд зам тавьсан эш үзүүлэгчийг төлөөлсөн юм. Ариун Сүнс үүнд нь түүнийг дэмжсэн; түүний ажил зам тавихын төлөө байсан цагт Ариун Сүнс түүнийг дэмжсэн. Гэвч хэрвээ тэр өөрийгөө Бурхан Өөрөө хэмээж, золин авралын ажлыг дуусгахын төлөө ирсэн гэж хэлсэн бол Ариун Сүнс түүнийг сахилгажуулах ёстой байлаа. Иоханы ажил хэчнээн агуу байсан нь хамаагүй, үүнийг Ариун Сүнс дэмжиж байсан ч гэсэн түүний ажил хил хязгааргүй байгаагүй юм. Ариун Сүнс үнэхээр түүний ажлыг дэмжсэн нь үнэн боловч тухайн үед түүнд өгсөн хүч чадал зам тавих явдлаар л хязгаарлагдаж байв. Тэрээр өөр ажил хийж огт чадаагүй, учир нь тэр бол Есүс биш, харин зам тавьсан Иохан байлаа. Тиймээс Ариун Сүнсний гэрчлэл гол түлхүүр нь боловч хүнээр хийлгэхээр Ариун Сүнсний зөвшөөрдөг ажил бүр ч илүү чухал юм. Иохан тухайн үед цангинасан гэрчлэл хүлээн аваагүй гэж үү? Түүний ажил ч бас асар их байгаагүй гэж үү? Гэхдээ түүний хийсэн ажил Есүсийнхээс хэтрээгүй, учир нь тэр ердөө л Ариун Сүнсний ашигласан хүн байсан бөгөөд Бурханыг шууд төлөөлж чадаагүй тул хийсэн ажил нь хязгаарлагдмал байлаа. Түүнийг зам тавих ажлаа дуусгасны дараа Ариун Сүнс түүний гэрчлэлийг хадгалахаа больж, ямар ч шинэ ажил түүнийг дагаагүй бөгөөд Бурханы Өөрийн ажил эхлэхэд тэр орхин явсан юм.

Муу ёрын сүнсэнд эзэмдүүлж, “Би бол Бурхан!” хэмээн бархиран хашхирдаг зарим хүн бий. Гэсэн ч, тэдний төлөөлдөг зүйл буруу учраас эцэстээ тэд илчлэгддэг.

Тэд Сатаныг төлөөлдөг ба Ариун Сүнс тэдэнд огт анхаарал хандуулдаггүй. Чи өөрийгөө хэчнээн өндөрт өргөмжилж, хэр чанга хашхирсан ч Сатанд харьяалагддаг бүтээгдсэн зүйл хэвээрээ л байна. Би хэзээ ч “Би бол Бурхан, Би бол Бурханы хайртай Хүү!” гэж хашхирдаггүй. Гэвч Миний хийдэг ажил бол Бурханы ажил юм. Би хашхирах хэрэгтэй гэж үү? Ямар ч өргөмжлөл хэрэггүй. Бурхан Өөрийнхөө ажлыг Өөрөө хийдэг бөгөөд хүн Түүнд байр суурь олгож, эсвэл хүндэт цол олгох хэрэггүй: Түүний ажил ялгамж чанар болон байр суурийг нь төлөөлдөг. Баптисм хүртэхээсээ өмнө Есүс, Бурхан Өөрөө байгаагүй гэж үү? Тэрээр Бурханы махбод болсон бие байгаагүй гэж үү? Тэр гэрчлэл хүлээн авсныхаа дараа л Бурханы цорын ганц Хүү болсон гэж хэлж мэдээж болохгүй биз дээ? Түүнийг ажлаа эхлэхээс ч өмнө Есүс гэдэг нэртэй хүн байгаагүй гэж үү? Чи шинэ зам гаргаж, эсвэл Сүнсийг төлөөлж чадахгүй. Сүнсний ажил болон хэлдэг үгийг илэрхийлж чадахгүй. Чи Бурханы Өөрийн ажлыг хийж чадахгүй, Сүнсний ажлыг ч хийж чадахгүй. Бурханы мэргэн ухаан, гайхамшиг, ойлгогдошгүй байдал болон хүнийг гэсгээдэг бүх зан чанар—энэ бүхнийг чи илэрхийлж чадахгүй. Тиймээс өөрийгөө Бурхан гэж зүтгэх нь нэмэргүй; чамд зөвхөн нэр л байх ба ямар ч мөн чанар байхгүй. Бурхан Өөрөө ирсэн боловч хэн ч Түүнийг таниагүй, гэсэн ч Тэр Өөрийн ажлыг үргэлжлүүлж, Сүнсийг төлөөлөн үүнийг хийдэг. Чи Түүнийг хүн юм уу Бурхан, Эзэн юм уу Христ гэж дуудсан ч, эсвэл Түүнийг эгч гэж дуудсан ч энэ нь хамаагүй. Харин Түүний хийдэг ажил Сүнснийх бөгөөд Бурханы Өөрийн ажлыг төлөөлдөг. Хүн Өөрийг нь ямар нэрээр дуудаж байгааг Тэр анхаардаггүй. Тэрхүү нэр Түүний ажлыг тодорхойлж чадах уу? Чи Түүнийг юу гэж дуудахаас үл хамааран, Бурханы тухайд гэвэл Тэрээр Бурханы Сүнсний махбод болсон бие юм; Тэр Сүнсийг төлөөлж, Сүнсээр сайшаагддаг. Хэрвээ чи шинэ эрин үед зориулсан замыг тавьж, хуучин эрин үеийг төгсгөж, шинэ эрин үеийг эхлүүлж, эсвэл шинэ ажил хийж чадахгүй бол чамайг Бурхан гэж нэрлэж болохгүй!

Ариун Сүнсний ашигладаг хүн хүртэл Бурханыг Өөрийг нь төлөөлж чадахгүй. Тийм хүн Бурханыг төлөөлж чадахгүйгээс гадна түүний хийдэг ажил ч бас Бурханыг шууд төлөөлж чадахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, хүний туршлагыг Бурханы удирдлага дотор шууд тавьж болохгүй бөгөөд энэ нь Бурханы удирдлагыг төлөөлж чадахгүй. Бурханы Өөрийн хийдэг ажил нь тэр чигтээ удирдлагын төлөвлөгөөндөө Түүний хийхээр зорьдог ажил бөгөөд агуу удирдлагатай хамаатай юм. Хүний хийдэг ажил нь өөрсдийн хувийн туршлагаар хангахаас бүрддэг. Энэ нь, өмнө явсан хүмүүсийнхээс давсан туршлагын шинэ замыг олж, Ариун Сүнсний удирдамж дор байх зуураа ах эгч нараа залж чиглүүлэхээс бүрддэг. Энэ хүмүүс хувийн туршлага, эсвэл сүнслэг хүмүүсийн сүнслэг бичвэрээр хангадаг. Тэднийг Ариун Сүнс ашигладаг хэдий ч тэдний хийдэг ажил зургаан мянган жилийн төлөвлөгөөний агуу удирдлагын ажилтай холбоогүй. Тэд бол биелүүлэх чиг үүрэг нь дуусаж, эсвэл амьдрал нь төгсөх хүртэл Ариун Сүнсний урсгал дахь хүмүүсийг удирдахын тулд өөр өөр цаг хугацаанд Ариун Сүнсний өргөсөн хүмүүс төдий юм.

Тэдний хийдэг ажил нь Бурханд Өөрт нь зориулсан тохиромжтой замыг бэлдэж, эсвэл газар дээрх Бурханы Өөрийн удирдлагын тодорхой талыг үргэлжлүүлэхийн төлөө байдаг. Энэ хүмүүс өөрсдөө Түүний удирдлагын агуу ажлыг хийж чадахгүй, шинэ замыг ч нээж чадахгүй, тэр ч бүү хэл тэдний хэн нь ч өмнөх эрин үеийн Бурханы бүх ажлыг төгсгөж чадахгүй. Тиймээс тэдний хийдэг ажил нь бүтээгдсэн зүйл чиг үүргээ биелүүлж байгааг л төлөөлдөг бөгөөд Бурхан Өөрөө үйлчлэлээ гүйцэтгэж байгааг төлөөлдөггүй. Яагаад гэвэл, тэдний хийдэг ажил Бурханы Өөрийн хийсэн ажилтай адилгүй. Шинэ эрин үеийг эхлүүлэх ажил нь Бурханы оронд хүний хийж чадах зүйл биш. Үүнийг Бурханаас Өөрөөс нь өөр хэн ч хийж чадахгүй. Хүний хийдэг бүх ажил нь бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ гүйцэтгэж байгаагаас бүрддэг бөгөөд Ариун Сүнс сэтгэлийг нь хөдөлгөж, эсвэл гэгээрүүлэх үед хүн үүнийг хийдэг. Энэ хүмүүсийн өгдөг удирдамж нь өдөр тутмын амьдрал дахь хэрэгжүүлэлтийн замыг болон Бурханы хүсэлтэй зохицолтойгоор хэрхэн үйлдэх ёстойг хүнд харуулахаас бүрддэг. Хүний ажил Бурханы удирдлагатай холбоогүй, Сүнсний ажлыг ч төлөөлдөггүй. Жишээ нь, Витнес Ли, Ватчман Ни хоёрын ажил нь зам заах явдал байсан юм. Зам шинэ ч бай, эсвэл хуучин ч бай, тухайн ажил Библийн дотор үлдэх зарчимд үндэслэсэн байв. Орон нутгийн чуулганыг сэргээхийн төлөө байсан ч бай, эсвэл барьж байгуулахын төлөө байсан ч бай, тэдний ажил чуулгануудыг байгуулахтай холбоотой байсан юм. Тэдний хийсэн ажил Есүс болон Түүний элчүүдийн дуусгалгүй орхисон ажил буюу Нигүүлслийн эрин үед цааш хөгжөөгүй ажлыг үргэлжлүүлжээ. Өөрсдийнхөө ажлаар тэдний хийсэн зүйл нь, тухайн үеийн ажилдаа Есүсийн дараагийн үеийнхнээсээ шаардсан зүйл болох толгойгоо бүтээх, баптисм хүртэх, талх хуваах, эсвэл дарс уух гэх мэтийг сэргээхийн төлөө байлаа. Тэдний ажил Библийг баримталж, Библи дотроос замыг эрж хайх явдал байсан гэж хэлж болно. Тэд ямар ч шинэ ахиц дэвшил гаргаагүй. Тиймээс тэдний ажлаас хүн, Библи доторх шинэ замуудын нээлтийг, мөн түүнчлэн илүү сайн, илүү бодитой хэрэгжүүлэлтүүдийг л харж чадна. Гэхдээ тэдний ажлаас хүн Бурханы одоогийн хүслийг олж чадахгүй, эцсийн өдрүүдэд Бурханы хийхээр төлөвлөдөг шинэ ажлыг олж бүр ч чадахгүй. Учир нь тэдний алхсан зам хуучин зам хэвээр байсан—ямар ч шинэчлэлт, ямар ч ахиц дэвшил байгаагүй. Тэд Есүсийн цовдлолын бодит баримттай зууралдаж, гэмшиж, нүглээ улайхыг хүмүүсээс шаардах дадлыг баримталж, эцсээ хүртэл тэвчсэн хүн аврагдах болно, эрэгтэй хүн бол эмэгтэй хүний тэргүүн бөгөөд эмэгтэй хүн нөхөртөө захирагдах ёстой гэсэн үгийг мөрдөж, тэр ч бүү хэл эгч нар номлож болохгүй, зөвхөн дуулгавартай дагах ёстой гэсэн уламжлалт үзлийг мөрдсөөр байв. Хэрвээ ийм маягийн удирдлагыг үргэлжлүүлэн мөрдсөн бол Ариун Сүнс шинэ ажлаа хэрэгжүүлж, хүмүүсийг дүрэм журмаас чөлөөлж, эсвэл тэднийг эрх чөлөө болон гоо сайхны ертөнц рүү хөтөлж хэзээ ч чадахгүй байх байлаа. Тиймээс эрин үеийг өөрчилдөг ажлын энэ үе шатанд Бурхан Өөрөө ажиллаж, үг хэлэх шаардлагатай байдаг; эс бөгөөс ямар ч хүн Түүний оронд ингэж хийж чадахгүй.

Одоог хүртэл энэ урсгалаас гаднах Ариун Сүнсний бүх ажил зогсонги байдалд орж, Ариун Сүнсний ашигласан хүмүүс өөрсдийн тулгуурыг алдсан. Тиймээс Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийн ажил нь Бурханы Өөрийн хийдэг ажлаас ялгаатай тул тэдний ялгамж чанар болон тэд хэний нэрийн өмнөөс үйлддэг нь ч бас өөр байдаг. Яагаад гэвэл, Ариун Сүнсний хийхээр зорьдог ажил өөр бөгөөд үүнээс үүдэн, адилхан ажил хийж байгаа хүмүүст өөр өөр ялгамж чанар болон байр суурийг олгодог. Ариун Сүнсний ашигладаг хүмүүс бас зарим нэг шинэ ажил хийж болох ба урьдын эрин үед хийгдсэн зарим ажлыг таягдан хаяж бас болох боловч тэдний хийдэг зүйл шинэ эрин үе дэх Бурханы зан чанар болон хүслийг илэрхийлж чадахгүй. Тэд зөвхөн хуучин эрин үеийн ажлыг халахын тулд л ажилладаг бөгөөд Бурханы Өөрийн зан чанарыг шууд төлөөлөх зорилгоор шинэ ажил хийхийн тулд ажилладаггүй. Иймд тэд хэчнээн олон хоцрогдсон хэрэгжүүлэлтийг цуцалж, эсвэл хэчнээн олон шинэ хэрэгжүүлэлт нэвтрүүлэх нь хамаагүй, хүнийг болон бүтээгдсэн зүйлийг төлөөлсөн хэвээр байдаг. Харин Бурхан Өөрөө ажил гүйцэтгэх үед хуучин эрин үеийн хэрэгжүүлэлтийг цуцалсныг ил тод зарладаггүй, шинэ эрин үе эхэлснийг шууд тунхагладаггүй. Тэр Өөрийнхөө ажилд шууд шулуухан байдаг. Тэрээр Өөрийн хийхээр зорьсон ажлыг шууд хийдэг; өөрөөр хэлбэл, Тэр Өөрийн авчирсан ажлыг шууд илэрхийлж, Өөрийн ажлыг анх зорьснооров шууд хийж, Өөрийн оршихуй болон зан чанарыг илэрхийлдэг. Хүний харж байгаагаар, Түүний зан чанар болон Түүний ажил ч гэсэн өмнөх эрин үеүдийнхээс өөр байдаг. Гэвч Бурханы Өөрийн үзэл бодлоор бол энэ нь ердөө Түүний ажлын үргэлжлэл, цаашдын хөгжил юм. Бурхан Өөрөө ажиллах үедээ үгээ илэрхийлж, шинэ ажлыг шууд авчирдаг. Эсрэгээрээ, хүн ажиллах үед энэ нь нягтлан цэгнэж, судлах замаар, эсвэл бусдын ажилд суурилсан хэрэгжүүлэлтийг системчлэх, мэдлэгээ өргөжүүлэх замаар хийгддэг. Өөрөөр хэлбэл, хүний хийдэг ажлын мөн чанар нь тогтсон дэг журмыг дагаж, “хуучин замаар шинэ гуталтай алхах” явдал мөн. Энэ нь, Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийн алхдаг зам ч гэсэн Бурханы Өөрийн нээсэн зам дээр үндэслэдэг гэсэн үг юм. Тиймээс, эцсийн эцэст хүн бол хүн, Бурхан бол Бурхан билээ.

Исаак Абрахамаас төрсөнтэй адилаар Иохан амлалтаар төрсөн. Есүсийн замыг засаж, ихээхэн ажил хийсэн боловч тэр Бурхан байгаагүй юм. Харин ч тэр ердөө Есүсийн төлөөх замыг тавьсан учраас эш үзүүлэгчдийн нэг байлаа. Түүний ажил ч бас асар их байсан бөгөөд түүнийг зам тавьсны дараа л Есүс Өөрийн ажлыг албан ёсоор эхэлсэн юм. Мөн чанартаа тэр зүгээр л Есүсийн төлөө хөдөлмөрлөсөн, түүний хийсэн ажил нь Есүсийн ажилд үйлчилж байв. Иоханыг зам засаж дууссаны дараа Есүс Өөрийн ажлыг буюу илүү шинэ, илүү тодорхой, илүү дэлгэрэнгүй ажлыг эхэлжээ. Иохан ажлын эхний хэсгийг л хийсэн; шинэ ажлын илүү их хэсгийг Есүс хийсэн юм. Иохан ч гэсэн шинэ ажил хийсэн боловч шинэ эрин үеийг эхлүүлсэн нэгэн байгаагүй. Иохан амлалтаар төрсөн бөгөөд түүний нэрийг тэнгэрэлч өгсөн. Тухайн үед зарим нь түүнийг аавынх нь нэрээр Зехариа гэж нэрлэхийг хүсэж байсан боловч эх нь “Энэ хүүхдийг тэр нэрээр нэрлэж болохгүй. Түүнийг Иохан гэж

нэрлэх ёстой” гэж хэлжээ. Энэ нь бүгд Ариун Сүнсний тушаалаар болсон юм. Есүсийг ч бас Ариун Сүнсний тушаалаар нэрлэсэн, Тэрээр Ариун Сүнснээс төрсөн бөгөөд Түүнийг Ариун Сүнс амласан байв. Есүс бол Бурхан, Христ, мөн хүний Хүү байлаа. Гэхдээ Иоханы ажил ч бас агуу байсан атал яагаад түүнийг Бурхан гэж нэрлээгүй вэ? Есүсийн хийсэн ажил болон Иоханы хийсэн ажлын хоорондяг ямар ялгаа байсан юм бэ? Иохан Есүсийн замыг зассан нэгэн байсан гэдэг нь цорын ганц шалтгаан байсан уу? Эсвэл үүнийг Бурхан урьдчилан тогтоосноос болсон уу? Хэдийгээр Иохан ч бас “Та нар гэмшицгээ: учир нь тэнгэрийн хаанчлал ойрхон байна” хэмээн хэлж, тэнгэрийн хаанчлалын тухай сайн мэдээг номлож байсан боловч түүний ажил цаашид хөгжилгүй, ердөө л эхлэлийг бүрдүүлсэн юм. Эсрэгээрээ, Есүс шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь төгсгөл болгосон, гэхдээ Тэр бас Хуучин Гэрээний хуулийг биелүүлсэн билээ. Түүний хийсэн ажил Иоханыхаас илүү агуу байснаас гадна Тэрээр бүх хүн төрөлхтнийг золин аврахаар ирсэн—Тэр ажлын тэрхүү үе шатыг гүйцэлдүүлсэн юм. Иоханы тухайд бол тэр зүгээр л замыг бэлдсэн. Хэдийгээр ажил нь агуу, үг нь олон, дагаж байсан шавь нар нь тоо томшгүй олон байсан боловч түүний ажил хүмүүст шинэ эхлэлийг авчрахаас хэтрээгүй. Хүн түүнээс амь, зам юм уу илүү гүн гүнзгий үнэнийг хүлээн аваагүй, мөн түүгээр дамжуулан Бурханы хүслийг ч ойлгоогүй. Иохан нь Есүсийн ажилд зориулсан шинэ газрыг нээж, сонгогдсон хүмүүсийг бэлдсэн агуу эш үзүүлэгч (Елиа) байсан юм; тэрээр Нигүүлслийн эрин үеийн анхдагч байлаа. Зүгээр л хэвийн хүний гадаад төрхийг нь ажиглаад ийм зүйлсийг ялган таних боломжгүй. Ялангуяа Иохан нэлээд их ажил хийсэн, мөн түүнчлэн түүнийг Ариун Сүнс амласан байсан ба ажлыг нь Ариун Сүнс дэмжиж байсан. Ийм болохоор хийдэг ажлаар нь л дамжуулан тэдний тус тусын ялгамж чанарыг хүн ялгаж чадна, учир нь хүний мөн чанарыг гадаад төрхөөс нь ялгаж мэдэх ямар ч аргагүй, мөн хүний хувьд, Ариун Сүнсний гэрчлэл юу болохыг тогтоох ямар ч аргагүй. Иохан, Есүс хоёрын хийсэн ажил адилгүй байсан бөгөөд өөр шинж чанартай байсан. Иохан Бурхан мөн байсан уу, үгүй юү гэдгийг хүн үүнээс тодорхойлж болно. Есүсийн ажил эхлүүлж, үргэлжлүүлж, дуусгаж, үр дүнд хүргэхийн төлөө байв. Тэрээр эдгээр үе шат болгоныг гүйцэтгэсэн байхад Иоханы ажил эхлэл тавихаас хэтрээгүй. Эхэндээ Есүс сайн мэдээ түгээж, гэмшлийн замыг тунхагласан ба дараа нь хүнд баптисм хүртээж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулж байлаа. Эцэст нь Тэр хүн төрөлхтнийг нүглээс золин аварч, бүхий л эрин үеийн төлөөх Өөрийн ажлыг дуусгасан юм. Түүнчлэн хаа сайгүй явж, хүнд номлож, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээжээ. Энэ талаараа Иохан Тэр хоёр адилхан байсан бөгөөд ялгаа нь Есүс шинэ эрин үеийг эхлүүлж, хүнд Нигүүлслийн эрин үеийг авчирсан юм. Түүний амнаас, Нигүүлслийн эрин үед хүний хэрэгжүүлэх ёстой үг, хүний дагах ёстой зам гарч, эцэст нь Тэрээр золин авралын ажлыг дуусгажээ. Ийм ажлыг Иохан хэзээ ч хийж чадахгүй байх байв. Иймд Бурханы Өөрийн ажлыг Есүс хийсэн ба Тэр бол Бурханыг шууд төлөөлдөг Бурхан Өөрөө байсан билээ. Хүний үзлээр бол,

амлалтаар төрж, Сүнснээс төрж, Ариун Сүнсээр дэмжүүлж, шинэ замуудыг нээдэг бүх хүн бол Бурхан юм. Энэ тайлбарын дагуу бол Иохан ч гэсэн Бурхан байх байсан ба Мосе, Абрахам, Давид … ч гэсэн мөн л Бурхан байх байв. Энэ нь туйлын инээдтэй зүйл биш гэж үү?

Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхээсээ өмнө Есүс ч бас Ариун Сүнсний хийсэн бүхэнтэй нийцүүлэн үйлдэж байсан хэвийн л нэг хүн байлаа. Тухайн үед Өөрийн ялгамж чанарыг мэдэж байсан эсэхээс үл хамааран Тэрээр Бурханаас ирсэн бүхнийг дуулгавартай дагаж байв. Түүний үйлчлэл эхлэхээс өмнө Ариун Сүнс Түүний ялгамж чанарыг хэзээ ч илчлээгүй. Өөрийн үйлчлэлийг эхэлснийхээ дараа л Тэр тэдгээр дүрэм журам, хуулийг хүчингүй болгож, Өөрийн үйлчлэлийг албан ёсоор гүйцэтгэж эхэлсний дараа л Түүний үгэнд эрх мэдэл, хүч чадал шингэсэн юм. Үйлчлэлээ эхэлснийх нь дараа л шинэ эрин үеийг бий болгох Түүний ажил эхэлжээ. Үүнээс өмнө Ариун Сүнс Түүний дотор 29 жилийн турш нуугдмал хэвээр үлдсэн, энэ хугацаанд Тэр зөвхөн хүнийг төлөөлсөн бөгөөд Бурханы ялгамж чанаргүй байсан юм. Түүнийг ажиллаж, үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэхэд Бурханы ажил эхэлсэн, хүн Өөрийг нь хэр их мэдэж байгааг үл хайхран Тэрээр дотоод төлөвлөгөөнийхөө дагуу ажлаа хийсэн бөгөөд Түүний хийсэн ажил Бурханыг Өөрийг нь шууд төлөөлж байлаа. Тухайн үед Есүс эргэн тойрныхоо хүмүүсээс “Та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээн асуусан юм. Тэд: “Та бол эш үзүүлэгчдээс хамгийн агуу нь бөгөөд бидний сайн эмч билээ” хэмээн хариулжээ. Бас зарим нь “Та бол бидний тэргүүн тахилч” гэсэн юм… Төрөл бүрийн хариулт өгөгдөж, зарим нь бүр Түүнийг Иохан, мөн Елиа гэж хэлжээ. Дараа нь Есүс Симон Петрт хандан “Чи Намайг хэн гэж хэлэх вэ?” хэмээн асуухад Петр “Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн” гэж хариулсан байна. Тэр үеэс эхлээд хүмүүс Тэр бол Бурхан гэдгийг мэддэг болсон. Түүний ялгамж чанар мэдэгдэх үед анх мэдсэн хүн нь Петр байсан бөгөөд түүний амаар энэ нь хэлэгджээ. Тэгэхэд Есүс “Чиний хэлсэн зүйлийг мах цус чамд илчлээгүй, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм” хэмээн өгүүлсэн. Түүнийг баптисм хүртсэний дараа бусад хүн энэ тухай мэдэж байсан эсэх нь хамаагүй, Түүний хийсэн ажил Бурханы өмнөөс хийгдсэн юм. Тэрээр ялгамж чанараа илчлэхийн тулд биш, Өөрийн ажлыг хэрэгжүүлэхийн тулд ирсэн билээ. Петр энэ тухай хэлсний дараа л Түүний ялгамж чанар хүнд ил болсон юм. Тэр бол Бурхан Өөрөө байсан гэдгийг мэдэж байгаа эсэхээс чинь үл хамааран, цаг нь болоход Тэр ажлаа эхлүүлсэн. Чи үүнийг мэдэж байсан ч бай, үгүй ч бай, Тэр Өөрийн ажлыг урьдынх шигээ үргэлжлүүлсэн юм. Чи үүнийг үгүйсгэсэн ч гэсэн Тэр мөн л Өөрийн ажлыг гүйцэтгэх байсан ба цаг нь болоход үүнийг хийх л байсан. Хүн махбодыг нь мэдээсэй гэсэндээ биш, харин Өөрийнх нь ажлыг хүлээн аваасай гэсэндээ Тэр ажлаа хийж, үйлчлэлээ хэрэгжүүлэхээр ирсэн билээ. Хэрвээ чи өнөө үеийн ажлын үе шат нь Бурханы Өөрийн ажил гэдгийг танин мэдэж чадаагүй бол чамд үзэгдэл дутагдаж байна. Гэсэн ч чи ажлын энэ үе шатыг үгүйсгэж чадахгүй; танин мэдэж чадахгүй байгаа чинь Ариун Сүнс ажиллахгүй байгааг, эсвэл Түүний

ажил буруу гэдгийг нотлохгүй. Одоогийн ажлыг Библи дэх Есүсийн ажилтай тулгаад, таарч тохирохгүй байгаа зүйлийг нь ашиглан ажлын энэ үе шатыг үгүйсгэдэг хүмүүс ч бий. Энэ нь харалган хүний үйлдэл биш гэж үү? Библид тэмдэглэгдсэн зүйлс хязгаарлагдмал; тэдгээр нь Бурханы ажлыг бүхэлд нь төлөөлж чадахгүй. Дөрвөн сайн мэдээ нийлээд зуугаас цөөхөн бүлэгтэй ба тэнд Есүс инжрийн модыг хараасан, Петр Эзэнийг гурван удаа үгүйсгэсэн, Есүс цовдлол болон амиллынхаа дараа шавь нартаа харагдсан, мацаг барих тухай сургаал, залбирлын тухай сургаал, салалтын тухай сургаал, Есүсийн төрөлт ба угийн бичиг, Есүс шавь нараа томилсон тухай гэх мэт хязгаарлагдмал тооны үйл явдлыг бичсэн байдаг. Гэсэн хэдий ч хүн тэдгээрийг эрдэнэс мэт үнэлж, бүр өнөөдрийн ажлыг тэдгээртэй харьцуулан шалгадаг. Тэр ч бүү хэл тэд Есүсийн амьдралдаа хийсэн бүх ажил нь ердөө тийм хэмжээтэй, Бурхан ердөө тийм зүйлийг л хийх чадвартай ба илүү ихийг хийж чадахгүй гэж итгэдэг. Энэ нь утгагүй хэрэг биш гэж үү?

Есүсийн газар дээр өнгөрүүлсэн хугацаа нь гучин гурван жил хагас байсан, өөрөөр хэлбэл, Тэр газар дээр гучин гурван жил хагас амьдарчээ. Энэ хугацааны ердөө гурван жил хагасыг л Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхэд зарцуулсан; үлдсэн хугацаанд нь Тэр зүгээр л хэвийн хүний амьдралаар амьдарсан юм. Эхэндээ Тэр синагогын үйл ажиллагаанд оролцож, тахилчдын Судар тайлбарлахыг болон бусдын номлохыг тэнд сонсдог байлаа. Тэрээр Библийн талаар ихээхэн мэдлэг олж авсан юм: Тэр тийм мэдлэгтэй төрөөгүй бөгөөд уншиж, сонссоноор л үүнийг олж авсан юм. Тэр арван хоёр настай байхдаа синагогын багш нараас “Эртний эш үзүүлэгчдийн зөгнөлүүд юу байсан бэ? Мосегийн хуулийн тухайд ямар вэ? Хуучин Гэрээний тухайд? Сүмд тахилчийн хувцастайгаар Бурханд үйлчилж байгаа хүний тухайд ямар вэ? …” гэх мэт асуултуудыг асуусан нь Библид тодорхой тэмдэглэгджээ. Тэр олон асуулт асуусан, учир нь Түүнд мэдлэг ч, ойлголт ч байгаагүй юм. Хэдийгээр Тэр Ариун Сүнснээс олдсон ч гэсэн бүхэлдээ хэвийн хүн болон төрсөн; Тэр тодорхой нэг онцгой зан араншинтай байсан боловч бас л хэвийн хүн байсан юм. Түүний мэргэн ухаан, бие хаа болон настай нь хамааралтайгаар тасралтгүй өссөн бөгөөд Тэр хэвийн хүний амьдралын үе шатыг туулжээ. Хүмүүсийн төсөөллөөр бол Есүс ямар ч хүүхэд нас, өсвөр насыг туулаагүй; Тэр төрмөгцөө гучин гурван настай хүний амьдралаар амьдарч эхэлсэн ба ажлаа дуусгаад цовдлогдсон. Тэр магадгүй хэвийн хүний амьдралын үе шатыг туулаагүй; юм иддэггүй, бусад хүнтэй ч харилцдаггүй байсан, хүмүүсийн хувьд Түүнийг зэрвэс харахад амаргүй байсан. Тэр Бурхан байсан учраас магадгүй Өөрийг нь харсан хүмүүсийг айлгах гажигтай нэгэн байсан байх. Махбодод ирдэг Бурхан хэвийн хүн шиг амьдардаггүй нь лавтай гэж хүмүүс итгэдэг; Тэр ариун хүн учраас шүдээ юм уу нүүрээ угаах хэрэггүй цэвэрхэн гэж тэд итгэдэг. Эдгээр нь гагцхүү хүний үзэл биш гэж үү? Библид Есүсийн хувь хүний амьдралын талаар тэмдэглээгүй зөвхөн Түүний ажлын тухай байдаг боловч Түүнд хэвийн хүн чанар байгаагүй, эсвэл Тэр гучин нас хүртлээ хэвийн хүний амьдралаар амьдраагүй

гэдгийг энэ нь нотолдоггүй. Тэр 29 насандаа ажлаа албан ёсоор эхэлсэн боловч тэр наснаас өмнө хүний хувиар өнгөрөөсөн Түүний бүх амьдралыг чи няцааж болохгүй. Библи ердөө тэр хугацааг тэмдэглэлдээ оруулаагүй; Түүний амьдрал нь хэвийн хүний амьдрал байсан ба бурханлаг ажлынх нь цаг үе байгаагүй тул бичиж тэмдэглэх хэрэггүй байлаа. Есүсийг баптисм хүртэхээс өмнө Ариун Сүнс шууд ажиллаагүй, харин Есүсийн үйлчлэлээ гүйцэтгэх өдөр болох хүртэл Түүний амьдралыг жирийн хүн байдлаар байлгаж байв. Хэдийгээр Тэр бие махбодтой болсон Бурхан байсан боловч хэвийн хүний адилаар нас бие гүйцэх үйл явцыг туулсан билээ. Нас бие гүйцэх үйл явцыг Библиэс хассан. Энэ нь хүний амийн өсөлтөд ямар ч тусламж үзүүлж чадахгүй учраас үүнийг хассан юм. Баптисм хүртэхээс өмнөх хугацаа нь нууцлаг үе байсан ба Тэр ямар ч тэмдэг, гайхамшиг үзүүлээгүй. Есүс баптисм хүртсэнийхээ дараа л хүн төрөлхтнийг золин аврах бүх ажлыг буюу нигүүлсэл, үнэн болон хайр, өршөөлөөр элбэг дэлбэг ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажлын эхлэл нь бас яг нарийндаа Нигүүлслийн эрин үеийн эхлэл байв; энэ шалтгааны улмаас үүнийг бичиж тэмдэглэж, өнөөг хүртэл дамжуулжээ. Энэ нь Нигүүлслийн эрин үеийн хүмүүсийн хувьд, Нигүүлслийн эрин үеийн замаар алхах, цовдлолын замаар алхах замыг нээж, бүхнийг үр дүнд хүргэхийн төлөө байв. Хэдийгээр энэ нь хүний бичиж тэмдэглэсэн зүйлээс гарсан боловч энд, тэндээ жаахан алдаатай байхыг үл тооцвол бүгд бодит баримт билээ. Гэсэн хэдий ч, тийм тэмдэглэлүүдийг худал гэж хэлж болохгүй. Тэмдэглэгдсэн хэрэг явдал бүхэлдээ баримттай, гагцхүү тэдгээрийг бичихдээ л хүмүүс алдаа гаргасан юм. Хэрвээ Есүс хэвийн, эгэл хүн чанартай байсан юм бол яаж тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвартай байсан байх юм бэ? хэмээн хэлэх зарим хүн бий. Есүсийн туулсан дөчин өдрийн сорилт нь гайхамшигт тэмдэг бөгөөд хэвийн хүний биелүүлж чадахгүй зүйл юм. Түүний дөчин өдрийн сорилт нь Ариун Сүнсний ажилд харьяалагдаж байсан; тэгэхээр Түүнд өчүүхэн төдий ч ер бусын зүйл байхгүй гэж хүн хэлж яахан чадах юм бэ? Түүний тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвар нь Тэр бол хэвийн хүн биш, харин ер бусын хүн байсан гэдгийг нотолдоггүй; ердөө л Ариун Сүнс Түүн шиг хэвийн хүн дээр ажиллаж, улмаар Түүнийг гайхамшиг үзүүлж, бүр ч агуу ажил хийх боломжтой болгосон юм. Үйлчлэлээ гүйцэтгэхээс өмнө, эсвэл Библид бичсэнчлэн Ариун Сүнс Өөр дээр нь бууж ирэхээс өмнө Есүс зүгээр л хэвийн хүн байсан ба огтхон ч ер бусын биш байв. Ариун Сүнс Түүн дээр бууж ирэх үед буюу үйлчлэлээ эхлүүлэх үед нь Түүнд ер бусын зүйл шингэжээ. Ийм маягаар хүн, Бурханы махбод болсон биед хэвийн хүн чанар байхгүй гэж итгэж эхэлдэг; түүнчлэн, бие махбодтой болсон Бурханд хүн чанар байхгүй, бурханлаг чанар л байдаг гэж эндүүрэн боддог. Мэдээж, Бурханыг ажлаа хийхээр газар дээр ирэх үед хүн ер бусын үйл явдлуудыг л хардаг. Түүний ажил болон үг тэдний хувьд ойлгохын аргагүй, хүрэхийн аргагүй байдаг учраас нүдээрээ харж, чихээрээ сонсдог зүйл нь бүгд ер бусын байдаг. Хэрвээ тэнгэрийн ямар нэг зүйлийг газарт авчирсан бол тэр нь ер бусын байхаас өөр яах юм бэ? Хүн ойлгошгүй, ухааршгүй, дэндүү гайхалтай, ухаалаг нууц болох

тэнгэрийн хаанчлалын нууцуудыг газарт авчрах үед—тэдгээр нь бүгд ер бусын байдаг бус уу? Гэхдээ, энэ нь хэчнээн ер бусын байсан ч бүх зүйл Түүний хэвийн хүн чанар дотор хийгддэг гэдгийг чи мэдэх ёстой. Бурханы махбод болсон биед хүн чанар байдаг; эс бөгөөс Тэр Бурханы махбод болсон бие биш байх байв. Өөрийнхөө цаг үед Есүс асар олон гайхамшиг үзүүлсэн. Тухайн үеийн израильчуудын харсан зүйл нь ер бусын зүйлсээр дүүрэн байсан; тэд тэнгэрэлчүүд болон элч нарыг харж, Еховагийн дуу хоолойг сонссон. Эдгээр нь бүгд ер бусын байгаагүй гэж үү? Мэдээж, өнөөдөр хүнийг ер бусын зүйлсээр мэхэлдэг зарим муу ёрын сүнс бий; өнөө үед Ариун Сүнсний хийдэггүй ажлаар дамжуулан хүнийг мэхлэх нь тэдний хувьд дуурайж байгаа явдал төдийхөн юм. Олон хүн гайхамшиг үйлдэж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг; эдгээр нь муу ёрын сүнсний ажлаас өөр юу ч биш, учир нь Ариун Сүнс өнөө үед тийм ажил хийхээ больсон бөгөөд Ариун Сүнсний тухайн үеийн ажлыг дараа нь дуурайсан бүх хүн бол үнэндээ муу ёрын сүнснүүд юм. Тухайн үед Израильд хийгдсэн бүх ажил ер бусын байсан хэдий ч Ариун Сүнс одоо тийм байдлаар ажилладаггүй бөгөөд одоогийн тийм ямар ч ажил бол Сатан дуурайж, дүр үзүүлж байгаа хэрэг, мөн түүний үймээн самуун юм. Гэхдээ ямар ч ер бусын зүйл муу ёрын сүнснээс гардаг гэж чи хэлж болохгүй—энэ нь Бурханы ажлын эрин үеэс хамаарна. Өнөө үед бие махбодтой болсон Бурханы хийсэн ажлыг аваад үз: Үүний ямар тал нь ер бусын биш вэ? Түүний үг чиний хувьд ойлгохын аргагүй, биелүүлэхийн аргагүй байдаг бөгөөд Түүний хийдэг ажлыг ямар ч хүн хийж чадахгүй. Түүний ойлгодог зүйлийг хүн ер ойлгох аргагүй, мөн Түүний мэдлэг хаанаас ирдгийг ч хүн мэдэхгүй. “Би ч гэсэн Тантай адил хэвийн хүн, тэгвэл би яагаад Таны мэддэг зүйлийг мэддэггүй юм бэ? Би насаар ахмад, туршлагаар арвин атал Та яаж миний мэддэггүй зүйлийг мэддэг юм бэ?” гэж зарим хүн хэлдэг. Хүний тухайд гэвэл, энэ бүхэн нь хүн хүрэхийн аргагүй зүйл юм. Тэгтэл, “Израильд хийгдсэн ажлын талаар хэн ч мэддэггүй, Библийг тайлбарлагчид хүртэл ямар ч тайлбар хийж чаддаггүй; Та яаж ер нь мэддэг юм бэ?” гэдэг хүмүүс ч бий. Эдгээр нь бүгд ер бусын хэрэг явдал биш гэж үү? Тэрээр ямар ч гайхамшиг туулаагүй мөртөө бүхнийг мэддэг; Тэрээр хамгийн амархнаар үг хэлж, үнэнийг илэрхийлдэг. Энэ нь ер бусын биш гэж үү? Түүний ажил махан биеийн хүрч чадах зүйлээс даван гардаг. Махан биетэй ямар ч хүний бодлоор үүнийг биелүүлэхийн аргагүй бөгөөд хүний уураг тархи үүнийг огтоос бодож чадахгүй. Хэдийгээр Тэр Библийг огт уншаагүй ч Израиль дахь Бурханы ажлыг ойлгодог. Тэр газар дээр зогсоод ярьж байгаа хэдий ч гуравдагч тэнгэрийн нууцуудын тухай ярьдаг. Эдгээр үгийг унших үед, “Энэ нь гуравдагч тэнгэрийн хэл биш гэж үү?” гэсэн мэдрэмж хүнийг эзэмддэг. Эдгээр нь бүгд хэвийн хүний биелүүлж чадах зүйлээс давсан хэрэг явдал биш гэж үү? Есүс дөчин өдөр мацаг барих тэр үе ер бусын байгаагүй гэж үү? Хэрвээ чи дөчин өдрийн мацаг нь ямартай ч ер бусын бөгөөд муу ёрын сүнсний үйл хэрэг мөн гэж хэлэх юм бол Есүсийг яллаж байгаа бус уу? Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээсээ өмнө Есүс хэвийн хүнтэй адил байсан. Тэр ч бас сургуульд

сурсан; тэгээгүй бол Тэр яаж уншиж, бичиж сурах юм бэ? Бурхан махбод болох үед Сүнс махбод дотор нуугдан оршиж байв. Гэсэн хэдий ч, хэвийн хүн байсан болохоор Түүний хувьд өсөж, нас бие гүйцэх үйл явцыг туулах шаардлагатай байсан бөгөөд танин мэдэх чадвар нь төлөвшиж, аливаа зүйлийг ялган салгаж чадах хүртлээ Тэр хэвийн хүн гэж тооцогдсон билээ. Хүн чанар нь төлөвшсөний дараа л Тэр Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж чадсан юм. Хэвийн хүн чанар нь хараахан төлөвшөөгүй, бодол нь үндэслэлгүй байх үед Тэр яаж үйлчлэлээ хэрэгжүүлж чадах юм бэ? Зургаа юм уу долоон настайдаа үйлчлэлээ хэрэгжүүлэхийг Түүнээс хүлээж болохгүй нь лавтай! Анх махбод болох үедээ Бурхан яагаад Өөрийгөө ил тод харуулаагүй юм бэ? Яагаад гэвэл, Түүний махбодын хүн чанар хараахан төлөвшөөгүй байсан; Өөрийн махбодын сэтгэхүйн үйл явц, мөн түүнчлэн энэ махбодын хэвийн хүн чанарыг Тэр бүрэн эзэмшээгүй байв. Ийм учраас ажлаа эхлэхээсээ өмнө Тэрээр, Өөрийн ажлыг махбодоор хийхэд хангалттай зэвсэглэсэн байх хэмжээнд хэвийн хүн чанар болон хэвийн хүний эрүүл саруул сэтгэлгээг зайлшгүй эзэмших шаардлагатай байсан билээ. Хэрвээ Тэр энэ ажилд тэнцэхгүй байсан бол Түүний хувьд үргэлжлүүлэн өсөж, төлөвших шаардлагатай байх байв. Есүс Өөрийн ажлыг долоо юм уу найман насандаа эхэлсэн бол хүн Түүнийг гоц авьяастан гэж үзэх байсан биш гэж үү? Бүх хүн Түүнийг хүүхэд гэж бодох байсан бус уу? Хэн Түүнд үнэмших юм бэ? Зогсож байгаа индрээсээ өндөргүй долоо юм уу найман настай хүүхэд—номлоход тохирох байсан уу? Хүн чанар нь төлөвшихөөс өмнө Тэр уг ажилд тэнцээгүй. Хараахан төлөвшөөгүй байсан Түүний хүн чанарын тухайд гэвэл, ажлын ихээхэн хэсэг нь ердөө биелүүлэхийн аргагүй байлаа. Махбод дахь Бурханы Сүнсний ажил нь бас өөрийн гэсэн зарчимд захирагддаг. Хэвийн хүн чанарыг эзэмших үедээ л Тэр ажлыг өөртөө авч, Эцгийн даалгаврыг хүлээн авч чадна. Зөвхөн тэр үед л Тэрээр Өөрийн ажлыг эхэлж болох юм. Хүүхэд насандаа Есүс, эрт цагт тохиолдсон ихэнх зүйлийн талаар ердөө ойлгож чадахгүй байсан ба синагогын багш нараас асууж байж л ойлгож авчээ. Хэрвээ Тэр дөнгөж ярьж сурангуутаа л ажлаа хийж эхэлсэн бол Түүний хувьд ямар ч алдаа гаргахгүй байх боломжтой байх байсан уу? Бурхан яаж алдаа гаргаж болох юм бэ? Тиймээс ажиллаж чаддаг болсныхоо дараа л Тэр Өөрийн ажлыг эхэлсэн; Тэр үүнийг хийх бүрэн чадвартай болтлоо ямар ч ажил гүйцэтгээгүй. Хорин есөн настайдаа Есүс аль хэдийн нэлээд төлөвшсөн байсан бөгөөд Түүний хүн чанар, хийх гэж байсан ажлаа явуулахад нь тохирохуйц болсон байлаа. Тэр үед л Бурханы Сүнс албан ёсоор Түүн дотор ажиллаж эхэлсэн юм. Тэр үед Иохан Түүнд зориулсан замыг нээхийн тулд долоон жилийн турш бэлдсэн бөгөөд ажлаа дуусгасны дараа шоронд оржээ. Тэгээд ачаа бүхэлдээ Есүс дээр унасан. Хэрвээ Тэр энэ ажлыг 21 юм уу 22 насандаа, хүн чанар нь дутуу дулимаг байх үед, дөнгөж нас биед хүрэх үедээ, мөн олон зүйлийг ойлгоогүй байхдаа хүлээн авсан бол хяналтыг гартаа авч чадахгүй байх байлаа. Тухайн үед, Есүсийг ажлаа эхлэхээс өмнө Иохан өөрийн ажлыг аль хэдийн хэсэг зуур хийчихсэн байсан ба тэгэхэд Есүс аль хэдийн дунд

эргэм настай байв. Тийм насандаа Түүний хэвийн хүн чанар нь Өөрийн хийх ёстой ажлыг хийхэд хангалттай болсон байлаа. Одоо, бие махбодтой болсон Бурхан ч бас хэвийн хүн чанартай бөгөөд хэдийгээр та нарын дундах арай ахмадуудтай нь харьцуулахуйц төлөвшөөгүй ч гэсэн энэхүү хүн чанар нь Түүний ажлыг биелүүлэхэд хэдийнээ хангалттай. Өнөөдрийн ажлын орчин нөхцөл Есүсийн үеийнхтэй бүхэлдээ адилхан биш. Есүс яагаад арван хоёр элчийг сонгосон бэ? Энэ нь бүгд Түүний ажлыг дэмжиж, хамтран ажиллахын төлөө байв. Нэг талаар энэ нь тухайн үеийн Түүний ажлын суурийг тавихын төлөө, харин нөгөө талаар, ирэх өдрүүд дэх Түүний ажилд суурь тавихын төлөө байсан юм. Тухайн үеийн ажилтай нийцүүлэн арван хоёр элчийг сонгох нь Есүсийн хүсэл, мөн түүнчлэн Бурханы Өөрийн хүсэл байлаа. Арван хоёр элчийг сонгоод, дараа нь газар сайгүй номлоход тэднийг залж чиглүүлэх ёстой гэж Тэр итгэж байв. Гэхдээ өнөөдөр та нарын дунд ингэх хэрэггүй! Бие махбодтой болсон Бурхан махбодоор ажиллах үед олон зарчим байдаг бөгөөд хүний ердөө ойлгодоггүй олон зүйл байдаг; Бурханыг хэмжихдээ, эсвэл Бурханд хэт их шаардлага тавихдаа хүн өөрийн үзлийг байнга ашигладаг. Гэхдээ одоо ч гэсэн, өөрсдийнх нь мэдлэг ганцхан өөрсдийнх нь үзлээс бүрддэг гэдгийг олон хүн огт мэддэггүй. Бурханы бие махбодтой болсон эрин үе юм уу газар ямар ч байсан бай, махбод дахь Түүний ажлын зарчим өөрчлөгдөлгүй үлддэг. Тэр махбод болчхоод махбодоосоо даван гарч ажиллаж чадахгүй; тэр ч бүү хэл махбод болчхоод махбодын хэвийн хүн чанар дотор ажиллахгүй байж чадахгүй. Эс бөгөөс Бурхан бие махбодтой болохын ач холбогдол үгүй болж, Үг махбод болсон гэдэг нь тэр чигтээ утгагүй болох байв. Түүнчлэн, Бурхан бие махбодтой болсныг зөвхөн тэнгэр дэх Эцэг (Сүнс) мэдэх ба өөр хэн ч, бүр махбод Өөрөө ч, эсвэл тэнгэрийн элч нар ч мэдэхгүй. Ийм болохоор махбод дахь Бурханы ажил бүр ч илүү хэвийн байж, Үг үнэхээр махбод болсныг бүр ч сайн илчилж чадах бөгөөд махбод гэдэг нь жирийн, хэвийн хүн гэсэн үг юм.

Зарим хүн: “Эрин үеийг яагаад Бурхан Өөрөө эхлүүлэх ёстой юм бол? Бүтээгдсэн зүйл Түүнийг орлож болохгүй гэж үү?” хэмээн гайхширч магадгүй. Бурхан махбод болсон нь шинэ эрин үеийг эхлүүлэх тодорхой зорилготой байсан ба мэдээж шинэ эрин үеийг эхлүүлэхдээ Тэрээр хуучин эрин үеийг ч нэгэн зэрэг дуусгасан байх болно гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Бурхан бол Эхлэл ба Төгсгөл; Тэр Өөрөө ажлаа явуулдаг тул Тэр Өөрөө л өмнөх эрин үеийг төгсгөх ёстой. Энэ нь Тэр Сатаныг ялж, дэлхийг байлдан дагуулдгийн баталгаа. Тэр Өөрөө хүмүүсийн дунд ажиллах бүрд энэ нь шинэ тулааны эхлэл байдаг. Шинэ ажлыг эхлүүлэлгүйгээр хуучныг нь дуусгана гэж мэдээж үгүй. Хуучныг нь дуусгаагүй байх үед Сатантай хийх тулаан хараахан төгсгөлдөө очоогүйг энэ нь нотолно. Зөвхөн Бурхан Өөрөө хүмүүсийн дунд ирж, шинэ ажил гүйцэтгэх л юм бол хүн Сатаны эзэмшлээс бүрэн чөлөөлөгдөж, шинэ амьдрал, шинэ эхлэлийг олж авч чадна. Эс бөгөөс, хүн үүрд хуучин эрин үед амьдарч, Сатаны хуучин нөлөөн дор үүрд амьдарна. Бурханы удирдаж буй эрин үе бүрд хүний нэг хэсэг сул чөлөөтэй болж,

тэгснээр хүн Бурханы ажилтай хамт шинэ эрин үе рүү урагшилдаг. Бурханы ялалт гэдэг нь Түүнийг дагадаг бүх хүний ялалт юм. Хэрвээ бүтээгдсэн хүн төрөлхтөнд эрин үеийг төгсгөх үүрэг өгсөн бол хүний үзэл бодлоор ч бай, эсвэл Сатаныхаар ч бай, энэ нь Бурханыг эсэргүүцэж, Түүнээс урвах, мөн Бурханд дуулгаваргүй байхаас цаашгүй байх байсан бөгөөд хүний ажил Сатаны хэрэгсэл болох байв. Бурханы Өөрийн эхлүүлсэн эрин үед хүн дуулгавартай байж, Бурханыг дагасан үед л Сатаныг бүрэн үнэмшүүлж чадна, учир нь энэ бол бүтээгдсэн зүйлийн үүрэг билээ. Тиймээс та нар зөвхөн дагаж, дуулгавартай байх хэрэгтэй бөгөөд үүнээс илүүг та нараас шаарддаггүй гэж Би хэлдэг. Энэ нь, хүн бүр үүргээ сахиж, тус тусын чиг үүргээ гүйцэтгэх гэдгийн учир юм. Бурхан Өөрийнхөө ажлыг хийдэг ба хүн Түүний оронд хийх хэрэггүй байдаг, мөн Тэр бүтээгдсэн зүйлийн ажилд ч оролцдоггүй. Хүн өөрийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Бурханы ажилд оролцдоггүй. Зөвхөн энэ л дуулгавартай байдал, мөн Сатаны ялагдлын баталгаа билээ. Бурхан Өөрөө шинэ эрин үеийг эхлүүлж дууссаныхаа дараа хүн төрөлхтний дунд ажиллахаар ирэхээ больдог. Зөвхөн тэр үед л хүн, бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлж, даалгавраа гүйцэтгэхээр шинэ эрин үе рүү албан ёсоор алхан ордог. Эдгээр нь Бурханы ажилладаг зарчмууд бөгөөд хэн ч зөрчиж болохгүй. Ийм маягаар ажиллах нь л ухаалаг, бас үндэслэлтэй юм. Бурханы ажлыг Бурхан Өөрөө хийдэг. Тэр Өөрийн ажлыг явуулж, Өөрийн ажлыг дуусгадаг. Тэрээр ажлыг төлөвлөж, удирддаг бөгөөд үүнээс ч илүүтэйгээр ажлыг үр дүнтэй болгодог. Библид өгүүлсэнчлэн “Би бол Эхлэл ба Төгсгөл; Би бол Тариалагч ба Хураагч.” Өөрийнх нь удирдлагын ажилтай холбоотой бүхнийг Бурхан Өөрөө хийдэг. Тэр бол зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний Захирагч; Тэр бүх зүйлийг гартаа атгаж байдаг тул өөр хэн ч Түүний ажлыг Түүний оронд хийж чадахгүй, хэн ч Түүний ажлыг дуусгаж чадахгүй. Дэлхий ертөнцийг бүтээсэн болохоор Тэрээр бүх ертөнцийг Өөрийнх нь гэрэлд амьдрахад хүргэнэ, бас бүхэл бүтэн эрин үеийг дуусгаж, улмаар Өөрийн бүх төлөвлөгөөг гүйцэлдүүлнэ!

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ 2

Есүс Иудейд ажиллаж байх үедээ үүнийгээ ил тод хийсэн, харин одоо Би та нарын дунд нууцаар ажиллаж, үг хэлдэг. Үл итгэгчид үүнийг огт мэддэггүй. Та нарын дундах Миний ажил гадна байгаа хүмүүст хаалттай. Эдгээр үг, эдгээр гэсгээлт болон шүүлтийг бусдад биш, зөвхөн та нарт мэдэгддэг. Энэ бүх ажлыг та нарын дунд хийдэг ба зөвхөн та нарт нээлттэй байдаг; үл итгэгчдийн дундаас хэн ч үүнийг мэддэггүй, учир нь цаг нь хараахан ирээгүй байна. Энд байгаа энэ хүмүүс гэсгээлт туулсныхаа дараа бүрэн төгс болгуулах дөхөж байгаа боловч гадна буй хүмүүс энэ тухай юу ч мэддэггүй. Энэ ажил хэтэрхий их нуугдмал! Тэдний хувьд, махбод болсон Бурхан нуугдмал байдаг боловч энэ урсгалд байгаа хүмүүст

нээлттэй байдаг гэж хэлж болно. Бурханд бүгд нээлттэй, бүгд илчлэгдсэн, бүгд чөлөөлөгдсөн байдаг боловч Түүнд итгэдэг хүмүүсийн хувьд л ийм байдаг; бусад нь болох үл итгэгчдийн тухайд бол юу ч мэдэгддэггүй. Та нарын дунд болон Хятадад одоогоор хийгдэж байгаа ажлыг тэдэнд мэдэгдэхгүйн тулд чанд битүүмжилдэг. Тэд энэ ажлыг олж мэдэх юм бол үүнийг яллаж, хавчлага тулгахаас өөрийг хийхгүй. Тэд үүнд итгэхгүй. Агуу улаан лууны улс буюу хамгийн их хоцрогдсон энэ газар ажиллах нь амар даалгавар биш билээ. Хэрвээ энэ ажлыг ил гарган тавьсан бол үргэлжлүүлэх боломжгүй байх байсан юм. Ажлын энэ үе шатыг энэ газарт явуулж ердөө чадахгүй. Хэрвээ энэ ажлыг ил тод гүйцэтгэсэн бол үүнийг тэд яаж зөвшөөрч чадах юм бэ? Энэ нь ажлыг бүр ч их эрсдэлд оруулах бус уу? Хэрвээ энэ ажлыг нууцлаагүй, харин ч Есүс гайхамшигтай байдлаар өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөдөг байсан цаг үеийнхтэй адилаар явуулсан бол диаволууд аль хэдийн үүнийг “олзолчихсон” байх биш үү? Тэд Бурханы оршин тогтнолыг тэвчиж чадах уу? Хэрвээ Би одоо хүмүүст номлож, сургамжлахын тулд синагогт орсон бол Намайг аль хэдийн хэдэн хэсэг болгочих байсан биш үү? Хэрвээ тэгсэн бол Миний ажил яаж үргэлжлэн явагдаж чадах юм бэ? Тэмдэг, гайхамшгийг ил тод харуулахгүй байгаагийн шалтгаан нь бүхэлдээ нуун далдлахын төлөө юм. Иймээс үл итгэгчдэд Миний ажил харагдахгүй, мэдэгдэхгүй, эсвэл олдохгүй. Хэрвээ ажлын энэ үе шатыг Нигүүлслийн эрин үед Есүсийн хийсэнтэй адил байдлаар хийсэн бол одоогийнх шигээ ийм тогтвортой байж чадахгүй байсан. Иймд энэ маягаар нууцаар ажиллах нь та нарт болон ажилд бүхэлд нь ач тустай. Газар дээрх Бурханы ажил дуусах үед, өөрөөр хэлбэл, энэ нууц ажил төгсөх үед ажлын энэхүү үе шат ил тод болно. Хятадад бүлэг ялагч байгааг бүгд мэднэ; Бурхан Хятадад махбод болсон бөгөөд Түүний ажил дууссаныг бүгд мэднэ. Зөвхөн тэр үед л, Хятад улс яагаад хараахан уруудан доройтож, нуран унахгүй байна вэ? гэдэг нь хүнд ойлгомжтой болно. Бурхан Өөрийн ажлыг Хятадад биечлэн хийж байгаа ба бүлэг хүмүүсийг ялагч болгон төгс болгосон болж таардаг.

Махбод болсон Бурхан ажлаа биечлэн хийж байх энэ хугацаандаа бүх бүтээлд бус, Өөрийг нь дагадаг зарим хүнд л Өөрийгөө харуулдаг. Тэрээр хүнд Өөрийн дүрийг харуулахын төлөө бус, ажлынхаа нэг үе шатыг гүйцэлдүүлэхийн тулд л махбод болсон юм. Гэхдээ, ажлаа Өөрөө хийх ёстой учраас Түүний хувьд махбодоор үүнийг хийх шаардлагатай. Энэ ажил дуусахад Тэр хүний ертөнцийг орхино; хожмын ажилд саад болох вий гэсэндээ Тэр хүн төрөлхтний дунд удаан хугацаагаар үлдэж чадахгүй. Олон нийтэд Түүний харуулдаг зүйл нь зөвхөн Түүний зөвт зан чанар болон Түүний бүх үйл хэрэг болохоос хоёр удаа махбод болох үеийнх нь дүр биш юм, учир нь Бурханы дүрийг зан чанараар нь л дамжуулан харж болохоос биш, Түүний махбод болсон биеийн дүрээр орлуулж болохгүй. Түүний махбодын дүр нь, махбодод ажиллаж байхад нь Түүнийг дагадаг хүмүүст буюу хязгаарлагдмал тооны хүмүүст л харагддаг. Ийм учраас одоо гүйцэтгэж байгаа ажлыг нууцаар хийдэг. Энэ нь, Есүс ажлаа хийх үедээ Өөрийгөө зөвхөн иудейчүүдэд

л харуулаад, бусад улс үндэстэнд Өөрийгөө хэзээ ч ил харуулаагүйтэй адил юм. Тиймээс Өөрийн ажлыг дуусгамагцаа Тэрээр үлдэлгүй, хүний ертөнцөөс даруй явсан; дараа нь, Түүний энэ дүр Өөрийгөө хүнд харуулсан юм биш, харин Ариун Сүнс ажлыг шууд гүйцэтгэсэн юм. Махбод болсон Бурханы ажил бүрэн дуусмагц Тэрээр зуурдын ертөнцийг орхин одох бөгөөд махбодод байхдаа хийсэнтэйгээ адилхан ажлыг дахин хэзээ ч хийхгүй. Үүний дараа ажлыг бүгдийг нь Ариун Сүнс шууд хийдэг. Энэ хугацаанд хүн Түүний махбодын дүрийг бараг харж чаддаггүй; Тэр Өөрийгөө хүнд огтхон ч харуулдаггүй, харин үүрд нуугдмал үлддэг. Махбод болсон Бурханы ажлын цаг хугацаа хязгаарлагдмал. Үүнийг тодорхой эрин үе, цаг хугацаа, улс үндэстэн, тодорхой хүмүүсийн дунд хийдэг. Энэ ажил нь Бурханы бие махбодтой байх үеийн ажлыг л төлөөлдөг; энэ нь эрин үеийг төлөөлж, Бурханы Сүнсний тодорхой нэг эрин үед хийсэн ажлыг төлөөлдөг ба Түүний ажлыг бүхэлд нь төлөөлдөггүй. Тиймээс махбод болсон Бурханы дүр бүх хүнд харагдахгүй. Олон түмэнд харагддаг зүйл нь Бурханы зөвт байдал, зан чанар бүхэлдээ болохоос биш, хоёр удаа махбод болох үеийн Бурханы дүр биш юм. Ганц дүр нь ч хүнд харагддаггүй, хоёр дүр нь хамтдаа ч харагддаггүй. Тиймээс Бурханы махбод болсон бие хийх учиртай ажлаа дуусгамагцаа газар дэлхийг орхин явах шаардлагатай, учир нь Тэрээр Өөрийн хийх учиртай ажлыг л хийхээр ирдгээс биш Өөрийн дүрийг хүмүүст харуулах гэж ирдэггүй. Бурхан хоёр удаа махбод болсноор бие махбодтой болохын ач холбогдлыг аль хэдийн гүйцээсэн боловч Өөрийг нь өмнө нь хэзээ ч хараагүй улс үндэстэнд Өөрийгөө ил тод харуулахгүй. Есүс зөвт байдлын Нар болж Өөрийгөө иудейчүүдэд дахин хэзээ ч харуулахгүй, мөн Чидун уулан дээр зогсож, бүх хүнд ч үзэгдэхгүй; иудейчүүд Иудейд байх үеийн Есүсийн хөрөг зургийг л харсан. Учир нь, бие махбодтой болсон Есүсийн ажил хоёр мянган жилийн өмнө дууссан; Тэр дахин хэзээ ч иудей хүний дүрээр Иудейд эргэн ирэхгүй, тэр ч бүү хэл Иудейд байх үеийн дүрээрээ Харь үндэстнүүдийн алинд ч Өөрийгөө харуулахгүй, учир нь махбод болсон Есүсийн дүр ердөө л иудей хүний дүр бөгөөд Иоханы харсан хүний Хүүгийн дүр биш билээ. Есүс дахин ирнэ гэж дагалдагчдадаа амласан хэдий ч Харь үндэстнүүд дэх бүх хүнд иудей хүний дүрээр ердөө харагдахгүй. Махбод болсон Бурханы ажил бол шинэ эрин үеийг нээх явдал гэдгийг та нар мэдэх учиртай. Энэхүү ажил хэдхэн жилээр хязгаарлагддаг ба Тэрээр Бурханы Сүнсний бүх ажлыг гүйцэлдүүлж чадахгүй, яг л иудей хүн болох Есүсийн дүр нь Иудейд ажиллаж байх үеийн Бурханы дүрийг л төлөөлж, цовдлолын ажил л хийж чадсантай адилхан. Есүс махбодод байх хугацаандаа эрин үеийг төгсгөх, эсвэл хүн төрөлхтнийг устгах ажлыг хийж чадаагүй. Тиймээс цовдлогдож, ажлаа дуусгасныхаа дараа Тэр хамгийн өндөрт гараад, хүнээс Өөрийгөө үүрд нуусан юм. Тэр цагаас эхлээд Харь үндэстнүүдийн үнэнч итгэгчид Эзэн Есүсийн илрэлийг харж чадалгүй, хананд наасан хөрөг зургийг нь л харах болсон. Энэ хөрөг зураг нь хүний зурсан зураг болохоос биш, Бурхан Өөрийгөө хүнд харуулах үеийн Бурханы дүр зураг биш юм. Бурхан хоёр удаа махбод болсон үеийн дүрээрээ олон түмэнд

Өөрийгөө ил харуулахгүй. Хүн төрөлхтний дунд Бурханы хийдэг ажил нь Өөрийнхөө зан чанарыг ойлгуулахын төлөө байдаг. Өөр өөр эрин үеийн ажлаар дамжуулан энэ бүхнийг хүнд харуулдаг; Есүсийн илрэлээр дамжуулахын оронд Өөрийн мэдэгдсэн зан чанар болон хийсэн ажлаар дамжуулан үүнийг хийдэг. Өөрөөр хэлбэл, махбодын дүрээр дамжуулж биш, харин дүр төрх, хэлбэр галбир бүхий, бие махбодтой болсон Бурханы гүйцэтгэсэн ажлаар дамжуулан Бурханы дүр хүнд илчлэгддэг; ажлаар нь дамжуулан Түүний дүр харагдаж, зан чанар нь ил болдог. Энэ бол махбодоор хийхийг хүсдэг ажлынх нь ач холбогдол юм.

Хоёр удаа бие махбодтой болсон Бурханы ажил дуусмагц Тэр зөвт зан чанараа шүтлэггүй бүх улс үндэстэн даяар үзүүлж, Өөрийн дүрийг олон түмэнд харуулж эхэлнэ. Тэрээр зан чанараа харуулж, үүгээрээ өөр өөр төрлийн хүмүүсийн төгсгөлийг тодорхой болгож, улмаар хуучин эрин үеийг бүхэлд нь төгсгөнө. Махбод дахь Түүний ажил асар өргөн хүрээнд өргөждөггүйн шалтгаан нь (Есүс зөвхөн Иудейд ажиллаж байсан шиг өнөөдөр Би зөвхөн та нарын дунд ажилладаг) махбод дахь Түүний ажил зааг, хязгаартай байдаг. Тэр ердөө богино хугацааны ажлыг эгэл жирийн, хэвийн махбодын дүрээр гүйцэтгэж байгаа; Тэр үүрдийн ажил хийж, эсвэл шүтлэггүй улс үндэстнүүдийн ард түмэнд харагдах ажлыг хийхийн тулд Бурханы махбод болсон энэ биеийг ашиглаагүй. Махбод дахь ажил нь цар хүрээгээрээ л хязгаарлагдмал байж болох (зөвхөн Иудейд, эсвэл зөвхөн та нарын дунд ажиллах гэх мэт) бөгөөд дараа нь эдгээр хил хязгаар дотор хийгддэг ажлаар дамжин цар хүрээ нь өргөжиж болно. Мэдээж өргөжилтийн ажлыг Түүний Сүнс шууд гүйцэтгэдэг бөгөөд тэр үед Түүний махбод болсон биеийн ажил байхаа болино. Учир нь махбод дахь ажил хил хязгаартай байдаг ба орчлон ертөнцийн бүх өнцөг буланд хүрч чадахгүй—үүнийг энэ нь биелүүлж чадахгүй. Махбод дахь ажлаар дамжуулан Түүний Сүнс дараагийн ажлыг нь гүйцэтгэдэг. Тиймээс махбодоор хийдэг ажил нь тодорхой хил хязгаар дотор гүйцэлддэг, эхлэлийн чанартай байдаг; үүний дараа Түүний Сүнс уг ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, түүнчлэн өргөжүүлсэн цар хүрээнд үүнийг хийдэг.

Бурхан эрин үеийг залж чиглүүлэхийн тулд л газар дээр ажиллахаар ирсэн; Тэрээр шинэ эрин үеийг нээж, хуучныг нь төгсгөл болгох л зорилготой. Тэрээр хүний амьдралын замналыг газар дээр амьдран харуулж, хүний ертөнц дэх амьдралын баяр гунигийг Өөрөө мэдрэх гэж, тодорхой нэг хүнийг Өөрийн гараар төгс болгох гэж, эсвэл хэн нэгний өсөж байгааг биечлэн харах гэж ирээгүй. Энэ бол Түүний ажил биш; Түүний ажил бол ердөө шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь төгсгөл болгох явдал. Өөрөөр хэлбэл, Тэр биечлэн шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь биечлэн төгсгөл болгоод, Өөрийн ажлыг биечлэн гүйцэтгэснээр Сатаныг ялна. Өөрийн ажлыг биечлэн хийх болгондоо Тэр тулааны талбарт хөл тавьж байгаа мэт байдаг. Эхлээд Тэр махбодод байхдаа дэлхий ертөнцийг ялан дийлж, Сатаныг ялдаг; Тэр бүх алдрыг эзэмшиж, бүхэл бүтэн хоёр мянган жилийн ажлын оршлыг эхлүүлж, тэгснээрээ газар дээрх бүх хүнийг алхах зөв замтай, амар

амгалан, баяр хөөртэй амьдрах амьдралтай болгодог. Гэхдээ Бурхан газар дээр хүнтэй хамт удаан амьдарч чадахгүй, учир нь Бурхан бол Бурхан бөгөөд эцсийн эцэст хүнтэй адилгүй юм. Тэр насан туршдаа хэвийн хүний амьдралаар амьдарч чадахгүй, өөрөөр хэлбэл, Тэр туйлын эгэл жирийн хүний байдлаар газар дээр оршин сууж чадахгүй, учир нь Түүний амьдралыг хангах хэвийн хүний хэвийн хүн чанар Түүнд тун бага байдаг. Өөрөөр хэлбэл, Бурхан яаж газар дээр гэр бүлтэй болж, ажил мэргэжилтэй болж, үр хүүхдээ өсгөж чадах билээ? Энэ нь Түүний хувьд шившигтэй хэрэг болох биш үү? Түүнд байдаг хэвийн хүн чанар нь, хэвийн хүний адилаар гэр бүл, ажил мэргэжилтэй болох боломжийг Түүнд олгохын тулд биш, хэвийн байдлаар ажиллах зорилготой байдаг. Түүний эрүүл ухаан, хэвийн оюун санаа, Түүний махбодын хэвийн хооллолт болон хувцаслалт нь хэвийн хүн чанартай гэдгийг нь батлахад хангалттай; хэвийн хүн чанартай гэдгээ нотлохын тулд Тэр гэр бүлтэй, эсвэл ажил мэргэжилтэй байх хэрэггүй. Ингэх шаардлага огт байхгүй! Бурхан газар дээр ирнэ гэдэг нь Үг махбод болж байгаа хэрэг; Тэр зүгээр л хүнд үгээ ойлгуулж, үгээ харуулж байгаа, өөрөөр хэлбэл, махбодоор гүйцэтгэдэг ажлыг хүнд харуулж байгаа юм. Хүмүүс Түүний махбодод тодорхой байдлаар хандах бус, харин эцсээ хүртэл дуулгавартай байх буюу Түүний амнаас гарах үг бүрд дуулгавартай байж, Түүний хийдэг бүх ажилд захирагдах нь Түүний санаа зорилго билээ. Тэр зүгээр л махбодод ажиллаж байгаа; Тэрээр Өөрийнх нь махбодын агуу, ариун байдлыг өргөмжлөхийг хүнээс зориуд шаардаж байгаа юм биш, харин Өөрийн ажлын мэргэн ухаан болон Өөрт байгаа бүх эрх мэдлийг хүнд харуулж байгаа юм. Тиймээс хэдийгээр Түүнд гайхамшигтай хүн чанар байгаа боловч Тэр огт зарладаггүй, хийх ёстой ажилдаа л анхаарлаа төвлөрүүлдэг. Бурхан махбод болсон ч Өөрийн хэвийн хүн чанарыг олон нийтэд зарлах юм уу гэрчлэхийн оронд яагаад зүгээр л хийхийг хүссэн ажлаа гүйцэтгэдэг болохыг та нар мэдэх ёстой. Тиймээс, бие махбодтой болсон Бурханаас та нар бурханлаг чанар нь юу болохыг л харж чадна; яагаад гэвэл, Өөрийнх нь хүн чанар бол хүний дуурайх зүйл гэж Тэр хэзээ ч зарладаггүй. Хүн бусдыг удирдах үедээ л тэдний бахдал бишрэл, итгэл үнэмшлийг илүү их олж авч, тэгснээрээ бусдыг манлайлахын тулд өөрөө хүн чанарын хувьд ямар вэ гэдэг тухайгаа ярьдаг. Гэтэл Бурхан гагцхүү Өөрийн ажлаар (өөрөөр хэлбэл, хүний хүршгүй ажил) дамжуулан хүнийг байлдан дагуулдаг; хүн Түүнийг гайхан бахдаж, эсвэл Түүнийг бишрэх эсэх нь чухал бус. Харин Тэрээр Өөрийг нь хүндэтгэх сэтгэлийг, эсвэл Өөрийнх нь ойлгогдошгүй байдлыг мэдрэх мэдрэмжийг л хүнд шингээдэг. Бурханд хүнээр бишрүүлэх шаардлага байхгүй; зан чанарыг нь хармагцаа чи Түүнийг хүндэтгэх нь л Түүнд хэрэгтэй. Бурханы хийдэг ажил бол Түүний Өөрийнх нь; хүн Түүнийг орлон хийж чадахгүй, мөн үүнд хүрч ч чадахгүй. Зөвхөн Бурхан Өөрөө л Өөрийнхөө ажлыг хийж, хүнийг шинэ амьдрал руу хөтлөхийн тулд шинэ эрин үеийг эхлүүлж чадна. Бурханы хийдэг ажил нь хүнийг шинэ амьдралтай болгож, шинэ эрин үе рүү оруулахын төлөө байдаг. Үлдсэн ажлыг нь хэвийн хүн чанартай, бусдаар

шагшигдан гайхагдсан хүмүүст хүлээлгэн өгдөг. Тиймээс, Нигүүлслийн эрин үед Тэрээр махбодод байсан гучин гурван жилийнхээ ердөө гурван жил хагасын хугацаанд л хоёр мянган жилийн ажлыг гүйцэлдүүлсэн юм. Бурхан Өөрийн ажлыг гүйцэтгэхээр газар дээр ирэх үедээ хоёр мянган жилийн ажлыг буюу бүхий л эрин үеийн ажлыг ердөө хэдхэн жилийн дотор үргэлж дуусгадаг. Тэрээр оройтуулдаггүй ба хойшлуулдаггүй; цөөн хэдхэн жилийн дотор хийж дуусгах гэсэндээ л олон жилийн ажлыг товчилдог. Яагаад гэвэл, Түүний биечлэн хийдэг ажил бүхэлдээ, шинэ замыг нээж, шинэ эрин үеийг удирдахын төлөө байдаг билээ.

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ 3

Бурхан ажлаа гүйцэтгэх үедээ ямар нэг бүтээн байгуулалт юм уу хөдөлгөөнүүдэд оролцдоггүй, харин Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхэлдэг. Түүнийг махбод болох болгонд энэ нь зөвхөн ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлж, шинэ эрин үеийг нээхийн төлөө л байдаг. Одоо Хаанчлалын эрин үе ирсэн, хаанчлалын сургалт ч бас ирсэн. Ажлын энэ үе шат нь хүний ажил биш, хүнийг тодорхой хэмжээнд боловсруулах явдал биш, харин Бурханы ажлын нэг хэсгийг л гүйцээх явдал юм. Түүний хийдэг зүйл хүний ажил биш, газар дэлхийг орхин явахаасаа өмнө хүнийг боловсруулахдаа тодорхой үр дүнд хүрэхийн төлөө биш; харин Өөрийн үйлчлэлийг биелүүлж, хийх учиртай ажлаа дуусгах явдал буюу газар дээрх ажилдаа зүй зохистой зохицуулалт хийж, улмаар алдрыг олж авах явдал юм. Бие махбодтой болсон Бурханы ажил нь Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийнхтэй адилгүй. Бурхан Өөрийн ажлыг газар дээр хийхээр ирэхдээ зөвхөн Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхэд л анхаардаг. Түүний үйлчлэлтэй холбоогүй бусад бүх хэрэг явдлын тухайд бол, Тэрээр бараг оролцдоггүй, бүр хараагүй мэт өнгөрүүлэхдээ тулдаг. Тэр зүгээр л хийх ёстой ажлаа хийдэг ба хүний хийх учиртай зүйлд хамгийн бага анхаардаг. Түүний хийдэг ажил нь гагцхүү Түүний байгаа эрин үе болон гүйцэтгэх учиртай үйлчлэлтэй нь хамаатай байдаг бөгөөд бусад бүх хэрэг явдал Түүний үйл ажиллагааны хүрээний гадна оршдог мэт байдаг. Тэрээр хүн төрөлхтний дунд нэг нь болж амьдрах тухай илүү үндсэн мэдлэгээр Өөрийгөө зэвсэглэдэггүй, нийгмийн илүү их ур чадварт ч суралцдаггүй, мөн хүний ойлгодог өөр бусад зүйлээр ч Өөрийгөө зэвсэглэдэггүй. Хүний эзэмших ёстой бүхнийг Тэр огт анхаардаггүй ба Өөрийнх нь үүрэг болох ажлыг л хийдэг. Иймээс, хүний харж байгаагаар бол, бие махбодтой болсон Бурхан маш их дутагдалтай болохоор хүнд байх учиртай олон зүйлд бүр анхаарлаа ч хандуулдаггүй, мөн тийм зүйлсийн талаар ямар ч ойлголтгүй байдаг. Амьдралын тухай ерөнхий мэдлэг, түүнчлэн биеэ авч явах, бусадтай харилцах зарчим Түүнд ямар ч хамаагүй мэт харагддаг. Гэхдээ чи бие махбодтой болсон Бурханаас өчүүхэн төдий ч хэвийн бус байдлыг мэдэрч чадахгүй. Өөрөөр хэлбэл, Түүний хүн чанар нь хэвийн хүний амьдрал болон уураг тархиных нь хэвийн ухааныг л

хадгалан, зөв бурууг ялгах чадварыг Түүнд өгдөг. Гэхдээ Тэр өөр юугаар ч зэвсэглэдэггүй, энэ бүхэн нь гагцхүү хүний (бүтээгдсэн зүйлийн) эзэмших ёстой зүйл юм. Бурхан үйлчлэлээ хэрэгжүүлэхийн тулд л махбод болдог. Түүний ажил бүхий л эрин үед чиглэдэг ба ямар нэг хүн юм уу газар луу биш, харин бүх орчлон ертөнцөд чиглэдэг. Энэ бол Түүний ажлын чиглэл, Түүний ажилладаг зарчим билээ. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, хүн үүнд оролцох ямар ч аргагүй. Бурхан махбод болох болгондоо тухайн эрин үеийн ажлыг авчирдаг бөгөөд хүнд Өөрийгөө илүү сайн ойлгуулж, мэдүүлэхийн тулд хүний дэргэд хорь, гуч, дөч, эсвэл бүр дал, наян жил амьдрах ямар ч санаа зорилго байдаггүй. Тэгэх шаардлагагүй! Ингэх нь Бурханы төрөлх зан чанарын талаарх хүний мэдлэгийг яавч гүнзгийрүүлэхгүй; харин ч хүний үзлийг л нэмэгдүүлж, хүний үзэл болон бодлыг хуучинсаг болгох байсан. Тиймээс бие махбодтой болсон Бурханы ажил яг юу болохыг та нар бүгд ойлговоос зохино. “Би хэвийн хүний амьдралыг туулахаар ирээгүй” гэж хэлснийг минь та нар мэдээж ойлгосон байлгүй дээ? “Бурхан хэвийн хүний амьдралаар амьдрахын тулд газар дээр ирээгүй” хэмээх үгийг та нар мартчихсан уу? Та нар Бурхан махбод болохын зорилгыг ойлгодоггүй, мөн “Бурхан яалаа гэж бүтээгдсэн зүйлийн амьдралыг туулах зорилгоор газар дээр ирэх юм бэ?” гэх үгийн утгыг ч мэддэггүй. Бурхан газар дээр гагцхүү Өөрийн ажлыг дуусгах гэж л ирдэг тул газар дээрх Түүний ажил түр зуурынх байдаг. Бие махбодоо чуулганыг удирдах гоц гойд хүн болгон боловсруулахад Бурханы Сүнсийг хүргэх санаа зорилгоор Тэр газар дээр ирдэггүй. Бурханыг газар дээр ирэхэд Үг махбод болдог; харин хүн Түүний ажлыг мэддэггүй ба Түүнд аливааг хүчээр тулгадаг. Гэхдээ, Бурхан бол Үг махбод болсон хэрэг болохоос бус, Бурханы үүргийг хэсэг зуур авахын тулд Бурханы Сүнсний боловсруулсан махан бие биш юм гэдгийг та нар бүгд ухаарах ёстой. Бурхан Өөрөө боловсруулалтын үр дүн биш, харин Үг махбод болсон хэрэг бөгөөд өнөөдөр Тэр та бүхний дунд Өөрийн ажлыг албан ёсоор гүйцэтгэдэг. Бурхан бие махбодтой болсон нь бодит үнэн гэдгийг та нар бүгд мэддэг, хүлээн зөвшөөрдөг ч үүнийг ойлгодог мэт авирладаг. Бие махбодтой болсон Бурханы ажлаас эхлээд Бурхан бие махбодтой болохын ач холбогдол, мөн чанарыг хүртэл, та нар эдгээрийг өчүүхэн ч ухаарч чаддаггүй бөгөөд зүгээр л үгийг үнэмшилтэйгээр цээжээр уншихад нь бусдыг дагадаг. Бие махбодтой болсон Бурхан чиний төсөөлдөгтэй адил гэж чи итгэж байна уу?

Бурхан гагцхүү эрин үеийг удирдаж, шинэ ажил явуулахын тулд махбод болдог. Та нар үүнийг ойлгох шаардлагатай. Энэ нь хүний чиг үүргээс ихээхэн өөр бөгөөд энэ хоёрыг эн зэрэгцүүлэн дурдаж болохгүй. Ажил гүйцэтгэхэд хүнийг ашиглахаас өмнө түүнийг удаан хугацааны турш боловсруулж, төгс болгох хэрэгтэй байдаг бөгөөд хүн чанар нь нэн өндөр түвшнийх байх хэрэгтэй байдаг. Хүн хэвийн хүн чанарын эрүүл ухаанаа хадгалж чаддаг байх ёстойгоор үл барам, цаашлаад бусадтай харилцахдаа биеэ авч явах олон дүрэм, зарчмыг ойлгох ёстой, түүнчлэн хүний мэргэн ухаан, ёс зүйн мэдлэгийн талаар бүр ч ихийг сурах ёстой. Энэ бол

хүний эзэмших ёстой зүйл. Гэвч махбод болсон Бурханы хувьд тийм биш, учир нь Түүний ажил хүнийг төлөөлдөггүй, хүний ажлыг ч төлөөлдөггүй; харин ч энэ нь Түүний оршихуйн шууд илэрхийлэл бөгөөд Түүний хийх учиртай ажлын шууд хэрэгжүүлэлт юм. (Мэдээж Түүний ажил тохиромжтой цагт хийгддэг болохоос санаандгүйгээр, хааш яаш хийгддэггүй бөгөөд үйлчлэлээ хэрэгжүүлэх цаг болоход энэ нь эхэлдэг.) Тэрээр хүний амьдрал, эсвэл хүний ажилд оролцдоггүй, өөрөөр хэлбэл, Түүний хүн чанарт эдгээрийн аль нь ч байдаггүй (гэхдээ энэ нь Түүний ажилд нөлөөлдөггүй). Цаг нь болоход Тэр Өөрийн үйлчлэлийг л хэрэгжүүлдэг; Түүний байр суурь ямар ч байсан Тэрээр хийх учиртай ажлаа зүгээр л хийдэг. Түүний талаар хүн юу мэддэг нь, мөн Түүний тухай ямар бодолтой байх нь Түүний ажилд ердөө нөлөөлдөггүй. Жишээ нь, Есүсийг ажлаа хийх үед Тэр яг хэн байсныг хэн ч мэдээгүй, гэхдээ Тэр зүгээр л ажлаа хийж байсан. Хийх учиртай ажлаа хийхэд нь эдгээрийн аль нь ч Түүнд саад болоогүй. Тиймээс Тэр эхэндээ Өөрийнхөө ялгамж чанарыг илчилж, зарлаагүй ба ердөө л хүнээр Өөрийгөө дагуулсан. Мэдээж энэ нь Бурханы даруу зан төдийгүй, бас махбодод ажилладаг арга зам нь байсан юм. Тэр ийм маягаар л ажиллаж чадах байлаа, учир нь хүн Түүнийг энгийн нүдээр хараад огт таних аргагүй байв. Хүн Түүнийг таньсан ч гэсэн Түүний ажилд тусалж чадахгүй байх байлаа. Үүнээс гадна, Тэрээр хүнд Өөрийнхөө махбодыг мэдэгдэх гэж бус, харин ажлаа хийж, үйлчлэлээ хэрэгжүүлэхийн тулд махбод болсон юм. Энэ шалтгааны улмаас Тэр Өөрийн ялгамж чанарыг зарлахад ямар ч ач холбогдол өгөөгүй. Хийх учиртай бүх ажлаа дуусгасных нь дараа Түүний бүхий л ялгамж чанар, байр суурь хүнд аяндаа тодорхой болчихно. Махбод болсон Бурхан чимээгүй байдаг ба хэзээ ч, юуг ч тунхагладаггүй. Тэрээр хүнд ч, эсвэл хүн Өөрийг нь яаж дагаж байгаад ч анхаарал хандуулдаггүй, харин зүгээр л үйлчлэлээ хэрэгжүүлэн, хийх учиртай ажлаа гүйцэтгэдэг. Түүний ажилд хэн ч саад тотгор учруулж чадахгүй. Түүний хувьд ажлаа дуусгах цаг ирэхэд үүнийг гарцаагүй дуусгаж, төгсгөлд нь аваачих ба хэн ч өөрөөр тушааж чадахгүй. Түүнийг ажлаа дуусгаад хүнийг орхин одсоны дараа л хүн Түүний хийдэг ажлыг ойлгох боловч бүрэн тодорхой ойлгож мөн л чадахгүй. Түүний анх ажлаа хийж эхэлсэн санаа зорилгыг бүрэн ойлгохын тулд хүн урт удаан хугацаа зарцуулна. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы эрин үеийн ажлыг хоёр хэсэгт хувааж болно. Нэг хэсэг нь, Бурханы Өөрийн махбод болсон биеийн хийдэг ажил болон Бурханы Өөрийн махбод болсон биеийн хэлдэг үгээс бүрддэг. Түүний махбодын үйлчлэл бүрэн дуусмагц Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийн хийх, ажлын нөгөө хэсэг үлддэг. Энэ үед хүн чиг үүргээ гүйцэтгэх ёстой болдог, учир нь Бурхан аль хэдийн замыг нээчихсэн ба хүн өөрөө алхах хэрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, махбод болсон Бурхан ажлын нэг хэсгийг гүйцэтгээд, дараа нь Ариун Сүнс болон Ариун Сүнсний ашигладаг хүмүүс энэ ажлыг залгамжилна. Тиймээс, энэ үе шатанд, махбод болсон Бурханы голчлон гүйцэтгэдэг ажил юунд хүргэдгийг хүн мэдэх ёстой бөгөөд Бурхан махбод болохын ач холбогдол яг юу болохыг болон Түүний хийх

учиртай ажил юу болохыг ойлгох ёстой болохоос хүнд тавьсан шаардлагын дагуу Бурханд шаардлага тавих ёсгүй. Энд хүний алдаа, түүний үзэл, үүнээс ч илүүтэйгээр түүний дуулгаваргүй байдал оршдог.

Бурхан махбод болох нь хүнд Өөрийн махбодыг мэдүүлэх зорилготой биш, эсвэл Бурханы махбод болсон бие болон хүний махан биеийн хоорондох ялгааг таниулах зорилготой биш; Бурхан хүний ялган таних чадварыг дадлагажуулахын тулд ч махбод болдоггүй, тэр ч бүү хэл, Бурханы махбод болсон биеийг шүтэн мөргөх боломжийг хүнд олгож, улмаар асар их алдрыг олж авах зорилгоор тэгдэггүй. Эдгээрийн аль нь ч Бурхан махбод болохын санаа зорилго биш. Бурхан хүнийг яллахын тулд, эсвэл зориуд хүнийг илчилж, түүнд хүндрэл учруулахын тулд махбод болдоггүй. Эдгээр зүйлийн аль нь ч Бурханы санаа зорилго биш. Бурхан махбод болох бүр нь ажлын зайлшгүй хэлбэр юм. Тэрээр хүний төсөөлдөг шалтгаанаар бус, харин Өөрийн илүү агуу ажил, илүү агуу удирдлагын төлөө ийнхүү үйлддэг. Бурхан зөвхөн ажлынхаа шаардлагаар л, хэрэгтэй үед л газар дээр ирдэг. Тэрээр зүгээр л эргэн тойрныг харах зорилгоор биш, харин Өөрийн хийх учиртай ажлыг гүйцэтгэхээр газар дэлхийд ирдэг. Эс бөгөөс Тэр яах гэж энэ ажлыг хийхийн тулд ийм хүнд ачаа үүрч, ийм агуу эрсдэл хүлээх билээ? Бурхан шаардлагатай үедээ л махбод болдог ба үргэлж өвөрмөц ач холбогдолтой байдаг. Хэрэв энэ нь ердөө хүмүүст Өөрийгөө харуулж, тэдний мэдлэгийн хүрээг тэлэхийн төлөө л байсан бол Тэрээр ийм хөнгөхнөөр хүмүүсийн дунд хэзээ ч ирэхгүй байсан нь лавтай. Тэрээр Өөрийн удирдлага болон агуу ажлын төлөө, мөн хүн төрөлхтнөөс илүү олныг олж авахын тулд газар дээр ирдэг. Түүнчлэн эрин үеийг төлөөлж, Сатаныг ялахаар ирдэг ба Сатаныг ялахын тулд махбодоор Өөрийгөө хувцасладаг. Үүнээс ч илүүтэйгээр, бүх хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэхийн тулд Тэр ирдэг. Энэ бүхэн Түүний удирдлагатай хамаатай, бүх орчлон ертөнцийн ажилтай хамаатай. Хэрвээ Бурхан хүмүүст Өөрийн махбодыг таниулж, хүмүүсийн нүдийг нээхийн тулд л махбод болсон бол яагаад бүх улсаар аялдаггүй юм бэ? Энэ нь туйлын амархан байх бус уу? Гэвч Тэр тэгээгүй, үүний оронд суурьшиж, хийх учиртай ажлаа эхлэхэд тохиромжтой газрыг сонгосон. Энэ махбод ганцаараа л гэхэд үлэмж ач холбогдолтой. Тэрээр эрин үеийг бүхэлд нь төлөөлж, бас бүхий л эрин үеийн ажлыг гүйцэтгэдэг; хуучин эрин үеийг төгсгөл болгохын сацуу шинэ эрин үеийг эхлүүлдэг. Энэ бүхэн нь Бурханы удирдлагатай холбоотой чухал асуудал бөгөөд энэ бүхэн нь газар дээр Бурханы гүйцэтгэхээр ирдэг ажлын нэг үе шатны ач холбогдол юм. Есүс газар дээр ирэхдээ зөвхөн зарим нэг үгийг хэлж, зарим ажлыг хийсэн; Тэр хүний амийн талаар санаа тавиагүй ба ажлаа дуусгамагцаа явсан. Өнөөдөр Би үг хэлж, Өөрийн үгийг та нарт дамжуулж дуусах үед, мөн та нар бүгд ойлгох үед амь чинь ямар байх нь хамаагүй, Миний ажлын энэ алхам дууссан байх болно. Хожим нь, Миний ажил дахь энэ алхмыг үргэлжлүүлж, эдгээр үгийн дагуу газар дээр үргэлжлүүлэн ажиллах зарим хүн байх ёстой; тэр үед хүний ажил болон хүний бүтээн байгуулалт эхэлнэ. Гэхдээ одоогоор, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж,

ажлынхаа нэг алхмыг гүйцээхийн тулд Бурхан Өөрийн ажлыг л хийдэг. Бурхан хүнийхтэй адилгүй байдлаар ажилладаг. Хүн цуглаан, чуулга уулзалтад дуртай, баяр ёслолд чухал ач холбогдол өгдөг байхад Бурхан яг хүний цуглаан болон уулзалтуудыг л хамгийн их жигшдэг. Бурхан хүнтэй албан бусаар хэлэлцэж, ярилцдаг; энэ бол ер бусын чөлөөтэй агаад та нарыг чөлөөлдөг Бурханы ажил билээ. Гэхдээ Би та нартай хамт цугларахыг туйлын их жигшдэг ба та нарынх шиг их дэг журамтай амьдралд дасаж чаддаггүй. Би дүрэм журмыг хамгийн их жигшдэг; тэдгээр нь хүнийг үйлдэл хийхээс айж, үг хэлэхээс айж, дуулахаас айж, нүд нь чам руу гөлрөн ширтэх хүртэл хэмжээнд хязгаарладаг. Би та нарын цугларалтын байдлыг туйлаас жигшдэг, мөн томоохон цуглаануудыг үнэхээр жигшдэг. Би ийм маягаар та нартай цугларахаас татгалздаг, учир нь ийм байдалтай амьдрахад дөнгөлүүлсэн мэт санагддаг бөгөөд та нар хэтэрхий их баяр ёслол, хэтэрхий олон дүрэм журмыг мөрддөг. Хэрвээ та нарт хүмүүсийг удирдах боломж олгосон бол та нар бүгдийг нь дүрэм журмын эзэмшил рүү хөтлөх бөгөөд та нарын удирдлага дор хүмүүс дүрэм журмыг хаях ямар ч аргагүй байх байсан; харин шашны уур амьсгал улам бүр эрчимжиж, хүний дадлууд нэмэгдсээр байх байлаа. Зарим хүн цугларах үедээ үг хэлж, ярьсаар байдаг ба хэзээ ч залхдаггүй, зарим нь арав гаруй хоног зогсолтгүй номлож чадна. Эдгээрийг бүгдийг нь хүний томоохон цуглаан, уулзалтууд гэж тооцдог; тэдгээр нь идэж уух болон эдэлж таашаах амьдралтай, эсвэл сүнсийг чөлөөлдөг амьдралтай огтхон ч хамаагүй. Бүгд уулзалт! Хамтран зүтгэгчдийн уулзалт, мөн том, жижиг цуглаанууд чинь бүгд Миний хувьд зэвүүцмээр байдаг бөгөөд Би хэзээ ч тэдгээрийг сонирхож байгаагүй. Энэ бол Миний ажилладаг зарчим: Би цуглааны үеэр номлохыг хүсдэггүй, мөн томоохон олон нийтийн цугларалт дээр ямар нэгэн юм тунхаглахыг ч хүсдэггүй, та бүхнийг хэдэн өдрийн онцгой хуралдаанд хуралдуулахыг бүр ч хүсдэггүй. Та нар цуглаан дээр бүгд ёсорхуу, зөв суух ёстой гэдгийг Би тохиромжтой гэж үздэггүй; ямар нэгэн ёслолын хязгаар дотор амьдарч байгааг чинь Би харах дургүй, үүнээс гадна Би та нарын тийм ёслолд оролцохоос татгалздаг. Та нар хэдий чинээ үүнийг хийнэ, энэ нь Надад төдий чинээ зэвүүцмээр санагддаг. Би та нарын энэ ёслол, дүрэм журмыг өчүүхэн төдий ч сонирхдоггүй; та нар тэдгээрийгээ хэчнээн сайн хийх нь хамаагүй Миний хувьд бүгд зэвүүцмээр байдаг. Та нарын зохицуулалт тохиромжгүй, эсвэл та нар хэтэрхий дорд байгаа юм биш; Би зүгээр л амьдралын хэв маягийг чинь жигшдэг, түүнээс гадна Би үүнд дасаж чаддаггүй. Та нар хийхийг хүсдэг ажлыг минь өчүүхэн ч ойлгодоггүй. Тухайн үед Есүс Өөрийн ажлыг хийж байхдаа, зарим газарт номлож дуусаад шавь нараа дагуулан хотоос гарч, ойлговол зохих замынх нь талаар тэдэнтэй ярилцдаг байв; Тэр ихэвчлэн ийм байдлаар ажилласан юм. Үй олон хүний дундах Түүний ажил ховорхон байлаа. Түүнээс шаарддаг зүйлийн чинь дагуу бол, махбод болсон Бурхан хэвийн хүний амьдралтай байх ёсгүй; Тэрээр ажлаа гүйцэтгэх ёстой ба сууж, зогсож, эсвэл алхаж байсан ч үг хэлэх ёстой. Тэр цаг ямагт ажиллах ёстой ба Өөрийн “үйл ажиллагааг” хэзээ ч зогсоож болохгүй, эс

тэгвээс Тэр үүргээ цалгардуулах байсан. Хүний эдгээр шаардлага нь хүний эрүүл ухаанд зохистой юу? Та нарын ёс жудаг хаана байна вэ? Та нар хэтэрхий ихийг шаардаж байгаа бус уу? Ажиллаж байхдаа Би чамаар шалгуулах хэрэгтэй гэж үү? Үйлчлэлээ хэрэгжүүлж байхдаа Би чамаар хянуулах хэрэгтэй гэж үү? Ямар ажил хийх ёстойгоо болон хэзээ хийх учиртайгаа Би сайн мэддэг; бусад хүн хөндлөнгөөс оролцох хэрэггүй. Би төдийлөн ихийг хийгээгүй мэт чамд санагдаж магадгүй боловч тэр үед Миний ажил дуусаж байдаг. Жишээ нь, Дөрвөн Сайн мэдээн дэх Есүсийн үгийг аваад үз: Тэдгээр нь ч бас хязгаарлагдмал байгаагүй гэж үү? Тухайн үед Есүс синагогт орж, номлол айлдах үедээ хамгийн ихдээ л хэдэн минутын дотор дуусгасан бөгөөд ярьж дууссаныхаа дараа шавь нараа дагуулан завь руу очиж, ямар ч тайлбаргүйгээр явж одсон. Хамгийн ихдээ л синагогт байсан хүмүүс үүнийг өөр хоорондоо хэлэлцсэн боловч Есүс үүнд оролцоогүй. Бурхан хийх учиртай ажлаа л хийдэг, үүнээс илүү юу ч хийдэггүй. Тэгвэл одоо, өдөрт ядаж хэдэн цагийн турш илүү их ярьж, үг хэлэхийг олон хүн Надаас хүсдэг. Та нарын харж байгаагаар, Бурхан үг хэлэхгүй л бол Бурхан байхаа болих бөгөөд үг хэлдэг Нэгэн л Бурхан юм. Та нар бүгд сохор! Бүгд мал адгуус шиг! Бүгд ямар ч эрүүл ухаангүй, мэдлэггүй юмнууд! Та нарт хэтэрхий олон үзэл байдаг! Шаардлага чинь дэндүү их! Та нар хүний үнэргүй! Бурхан юу гэснийг ядаж ойлгодоггүй! Бүх илтгэгч болон уран илтгэгч бол Бурхан, та нарыг үгээр хангахад бэлэн байгаа хэн боловч та нарын эцэг гэж та нар итгэдэг. Надад хэл дээ, сайхан галбиртай, содон дүр төрхтэй та бүхэнд өчүүхэн төдий ч гэсэн эрүүл ухаан байгаа юу? Та нар тэнгэрнарыг одоогоор мэдэх үү! Та нар бүгдээрээ, шунахай агаад авлигад автсан албан тушаалтантай адилхан тул эрүүл ухааныг ойлгож яаж чадах билээ? Зөв бурууг ялгаж яаж чадах билээ? Би та нарт ихийг хайрласан боловч та нарын дундаас хэчнээн нь үүнийг үнэлсэн бэ? Үүнийг хэн бүрэн эзэмшсэн вэ? Өнөөдөр алхдаг замыг чинь хэн нээснийг та нар мэддэггүй тул Надад үргэлжлүүлэн шаардлага тавьж, эдгээр хөгийн, утгагүй шаардлагыг тавьдаг. Ичсэнээсээ болоод нүүр чинь улайхгүй байна уу? Би хангалттай яриагүй гэж үү? Би хангалттай хийгээгүй гэж үү? Та нарын дундаас хэн Миний үгийг үнэт эрдэнэс мэт үнэхээр нандигнадаг вэ? Та нар Миний өмнө Надад долигонодог боловч Миний ардуур худлаа ярьж, хуурдаг! Та нарын үйлдэл хэтэрхий жигшмээр бөгөөд Миний дургүйг хүргэдэг! Та нар амьдралаа өөрчлөхийн тулд биш, харин нүдээ хужирлаж, мэдлэгийн хүрээгээ тэлэх гэсэндээ л үг хэлж, ажиллахыг Надаас гуйдгийг чинь Би мэднэ. Би та нарт маш ихийг хэлсэн. Та нарын амьдрал аль хэдийн өөрчлөгдчих ёстой байсан, тэгтэл та нар яагаад одоо ч гэсэн хуучин байдлаа давтсаар байдаг юм бэ? Та нар Миний үгийг дээрэмдүүлчхээд, тэдгээрийг хүлээн аваагүй юм гэж үү? Үнэнийг хэлэхэд Би та нар шиг ийм доройтмол хүмүүст өөр юу ч хэлэхийг хүсдэггүй—энэ нь хий дэмий байх болно! Би ийм их үр ашиггүй ажил хийхийг хүсдэггүй! Та нар амийг олж авахыг биш, харин зөвхөн мэдлэгийн хүрээгээ тэлж, эсвэл нүдээ хужирлахыг л хүсдэг! Та нар бүгд өөрсдийгөө хуурч байна! Би та нараас асууя, та нартай нүүр тулан ярьсан зүйлийн

минь хэр ихийг та нар хэрэгжүүлсэн бэ? Та нар бусдыг мэхлэхийн тулд заль гаргахаас өөрийг хийдэггүй! Та нарын дунд байгаа, үзэгч мэт харах дуртай хүмүүсийг Би жигшдэг бөгөөд сониуч зан чинь Миний хувьд гүнээ зэвүүцмээр байдаг. Хэрвээ үнэн замыг эрэлхийлэхийн тулд, эсвэл үнэнээр цангасандаа энд ирээгүй бол та нар Миний жигшлийн бай юм! Та нар сониуч зангаа хангахын тулд, эсвэл шуналт хүслийнхээ аль нэгийг биелүүлэхийн тулд л Миний ярихыг сонсдог гэдгийг Би мэднэ. Та нарт үнэний оршин тогтнолыг эрж хайх, эсвэл амь руу орох зөв замыг судалж шинжлэх бодол байдаггүй; эдгээр шаардлага та нарын дунд ердөө оршдоггүй. Та нар Бурханыг судалж, гайхан бишрэх тоглоом мэт үздэгээс цаашгүй. Та нар амийг эрэлхийлэхдээ хэтэрхий бага хүсэл тэмүүлэлтэй байдаг боловч сониуч хүсэл чинь их байдаг! Тийм хүмүүст амийн замын тайлбарлах нь оргүй хоосонтой ярихтай адил; Би огт ярихгүй байсан нь дээр! Би та нарт хэлье! Хэрвээ та нар зүгээр л зүрх сэтгэл дэх хоосон зайгаа дүүргэхээр хичээж байгаа бол Над руу ирэхгүй байсан чинь дээр! Та нар амь олж авахад ач холбогдол өгөх учиртай! Өөрсдийгөө бүү хуур! Та нар сониуч зангаа амийн эрэл хайгуулынхаа үндэс болгож, эсвэл өөрсдөд чинь үгээ хэлэхийг Надаас гуйх шалтаг болгон ашиглахгүй байсан нь дээр. Энэ бүхэн нь та нарын тун сурамгай хийдэг заль мэх юм! Би чамаас дахин асууя: Орохыг шаардсан зүйлийн минь хэр их рүү чи үнэхээр орсон бэ? Чамд хэлсэн бүхнийг минь чи ухаарсан уу? Чамд хэлсэн бүхнийг чи хэрэгжүүлж амжсан уу?

Эрин үе бүрийн ажлыг Бурхан Өөрөө эхлүүлдэг боловч Бурхан ямар ч замаар ажилласан бай, Тэрээр та нарын өмнөөс ямар нэг хөдөлгөөн эхлүүлэх гэж, тусгай хурал хийх гэж, эсвэл ямар нэг байгууллага байгуулах гэж ирдэггүй гэдгийг чи мэдэх ёстой. Тэр Өөрийн хийх учиртай ажлыг гүйцэтгэхийн тулд л ирдэг. Түүний ажил ямар нэг хүний хязгаарлалтад автдаггүй. Тэр Өөрийн ажлыг хүссэнээрээ хийдэг; хүн үүний талаар юу бодож, юу мэдэж байгаагаас үл хамааран Тэрээр Өөрийн ажлыг гүйцэтгэхэд л анхаарлаа хандуулдаг. Дэлхийг бүтээснээс эхлээд өнөөдрийг хүртэл ажлын гурван үе шат байсан; Еховагаас Есүс хүртэл, Хуулийн эрин үеэс Нигүүлслийн эрин үе хүртэл Бурхан хэзээ ч хүмүүст зориулан тусгай хурал зарлаагүй, мөн олон улсын тусгай хурал зарлан хуралдуулж, тэгснээрээ Өөрийн ажлын хүрээг өргөжүүлэхийн төлөө бүх хүн төрөлхтнийг хэзээ ч цуглуулаагүй. Түүний хийдэг бүхэн нь, бүхий л эрин үеийн эхний ажлыг зөв цаг, зүй зохистой орон зайд гүйцэтгэж, улмаар эрин үеийг эхлүүлж, хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэх явдал юм. Тусгай хурлууд нь хүний цугларалт юм; хүмүүсийг цуглуулж, баяр тэмдэглэх нь хүний л ажил. Бурхан амралтын өдрүүдийг мөрддөггүй, цаашлаад тэдгээрт зэвүүцдэг; Тэрээр тусгай хурал зарлан хуралдуулдаггүй ба тэдгээрийг ч бас зэвүүцмээр гэж үздэг. Одоо чи бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил яг юу болохыг ойлгосон байх ёстой!

БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН НУУЦ 4

Та нар Библийн ар дахь түүх болон туурвилыг мэдэх ёстой. Бурханы шинэ ажлыг хүлээн аваагүй хүмүүст ийм мэдлэг байдаггүй. Тэд мэддэггүй. Хэрвээ чи тэдэнд мөн чанарын эдгээр асуудлын талаар ний нуугүй ярьсан бол тэд Библийг хамгаалан зүтгэхээ болих байсан. Тэд, энэ үг биелсэн үү? Тэр үг биелсэн үү? хэмээн зөгнөгдсөн зүйлсийг байнга ухаж төнхөж байдаг. Тэд Библийн дагуу сайн мэдээг хүлээн авч, Библийн дагуу сайн мэдээ номлодог. Бурханд итгэх итгэл нь Библийн үгэнд тулгуурладаг; Библигүйгээр тэд Бурханд итгэхгүй. Тэд ийм байдалтай амьдарч, Библийг ухаж төнхөх байдлаар амьдардаг. Тэд дахин нэгэнтээ Библийг ухаж төнхөн, чамаас тайлбар хүсэх үед чи ийнхүү хэлнэ: “Эхлээд үг бүрийг баталгаажуулахгүй байцгаая. Харин Ариун Сүнс хэрхэн ажилладгийг харцгаая. Өөрсдийнхөө алхдаг замыг авч үзээд, энэ зам Ариун Сүнсний ажилтай үнэхээр нийцэж байгаа эсэхийг харахын тулд үнэнтэй харьцуулъя, мөн Ариун Сүнсний ажлыг ашиглаад тийм зам зөв эсэхийг шалгая. Энэ үг, эсвэл тэр үг зөгнөсний дагуу биелсэн эсэхийн тухайд гэвэл хүмүүс бид хошуу дүрэх ёсгүй. Харин ч бид Ариун Сүнсний ажлыг болон Бурханы хийсээр ирсэн сүүлийн үеийн ажлын талаар ярьсан нь дээр.” Библи дэх зөгнөлүүд бол тухайн үед эш үзүүлэгчдийн дамжуулсан Бурханы үг болон Бурханы ашиглаж байсан хүмүүсийн, онгод хүртээд бичсэн үг юм; Бурхан Өөрөө л тэдгээр үгийг тайлбарлаж чадна, Ариун Сүнс л тэдгээр үгийн утга учрыг мэдэгдэж чадна, мөн Бурхан Өөрөө л долоон лацыг эвдэж, хуйлмал номыг нээж чадна. “Чи Бурхан биш, би ч бас биш болохоор хэн Бурханы үгийг хөнгөхнөөр тайлбарлаж зүрхлэх юм бэ? Чи тэдгээр үгийг тайлбарлаж зүрхлэх үү? Эш үзүүлэгч Иеремиа, Иохан, Елиа нар энд байсан ч гэсэн тэдгээр үгийг тайлбарлаж зүрхлэхгүй, учир нь тэд бол Хурга биш билээ. Гагцхүү Хурга л долоон лацыг эвдэж, хуйлмал номыг нээж чадна, өөр хэн ч Түүний үгийг тайлбарлаж чадахгүй. Би Бурханы нэрийг булаан авч зүрхлэхгүй, Бурханы үгийг тайлбарлахаар оролдож бүр ч зүрхлэхгүй. Би Бурханд дуулгавартай байдаг нэгэн л байж чадна. Чи Бурхан юм уу? Бурханы бүтээлүүдийн нэг нь ч хуйлмал номыг нээж, тэдгээр үгийг тайлбарлаж зүрхлэхгүй, иймээс би ч гэсэн тайлбарлаж зүрхлэхгүй. Чи тэдгээрийг тайлбарлахаар оролдоогүй нь дээр. Хэн ч тэдгээрийг тайлбарлахаар оролдох ёсгүй. Ариун Сүнсний ажлын талаар ярилцацгаая; хүн үүнийг л хийж чадна. Би Ехова, Есүс хоёрын ажлын талаар бага зэрэг мэддэг боловч тийм ажлыг биечлэн туулаагүй болохоор багахан хэмжээнд л энэ талаар ярьж чадна. Тухайн үеийн Исаиа, эсвэл Есүсийн хэлсэн үгийн утгын тухайд гэвэл би ямар ч тайлбар хийхгүй. Би Библийг судалдаггүй, харин Бурханы өнөөгийн ажлыг дагадаг. Чи үнэндээ Библийг бяцхан хуйлмал ном мэт үздэг ч энэ нь Хурганы л нээж чадах зүйл биш гэж үү? Хурганаас өөр хэн үүнийг нээж чадах юм бэ? Чи Хурга биш, би өөрийгөө Бурхан Өөрөө гэж хэлж бүр ч зүрхлэхгүй, иймээс Библийг судалж, ухаж төнхөхгүй байцгаая. Ариун Сүнсний хийсэн ажлыг буюу Бурханы Өөрийн хийсэн

өнөөгийн ажлыг хэлэлцсэн нь хавьгүй дээр. Бурханы ажилладаг зарчмууд юу болохыг, Түүний ажлын мөн чанар юу болохыг хараад, өнөөдөр бидний алхаж буй зам зөв эсэхийг магадлахын тулд эдгээрийг ашиглацгаая, ийм маягаар үүнийг тодорхой болгоцгооё" гэж чи хэлнэ. Хэрвээ та нар, ялангуяа шашны ертөнц дэх хүмүүст сайн мэдээ номлохыг хүсвэл Библийг ойлгож, үүний дотоод түүхүүдийг эзэмшсэн байх ёстой; эс бөгөөс, чиний хувьд сайн мэдээ номлох арга үгүй. Чи ерөнхий дүр зургийг эзэмшиж, Библийн үхмэл үгсийг нягтлан шинжлэхээ больж, зөвхөн Бурханы ажил болон амь-үнэний талаар ярьдаг болмогцоо үнэн сэтгэлээсээ эрж хайдаг хүмүүсийг олж авч чадна.

Еховагийн хийсэн ажил, Түүний тогтоосон хуулиуд, хүний амьдралыг залж чиглүүлдэг зарчмууд, Хуулийн эрин үед хийсэн ажлынх нь агуулга, хууль тогтооход өгсөн ач холбогдол, Нигүүлслийн эрин үе дэх ажлынх нь ач холбогдол болон сүүлчийн энэ үе шатанд Бурхан ямар ажил хийдэг: эдгээр нь та нарын ойлгох ёстой зүйл билээ. Эхний үе шат нь Хуулийн эрин үеийн ажил, хоёр дахь нь Нигүүлслийн эрин үеийн ажил бөгөөд гурав дахь нь эцсийн өдрүүдийн ажил юм. Та нар Бурханы ажлын эдгээр үе шатыг тодорхой ойлгох ёстой. Эхнээсээ дуустлаа нийт гурван үе шат байдаг. Ажлын үе шат болгоны мөн чанар юу вэ? Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний ажилд хэдэн үе шат хэрэгжсэн бэ? Эдгээр үе шатыг хэрхэн гүйцэтгэсэн, мөн яагаад тус бүрийг нь тодорхой арга замаар гүйцэтгэдэг вэ? Эдгээр нь бүгд амин чухал асуултууд билээ. Эрин үе болгоны ажилд бэлгэдлийн үнэ цэн байдаг. Ехова ямар ажил гүйцэтгэсэн бэ? Яагаад Тэр яг тийм маягаар хийсэн бэ? Яагаад Түүнийг Ехова гэж нэрлэсэн бэ? Бас Нигүүлслийн эрин үед Есүс ямар ажил гүйцэтгэсэн, Тэр ямар байдлаар үүнийг хийсэн бэ? Ажлын үе шат болгон нь, эрин үе бүр нь Бурханы зан чанарын ямар талуудыг төлөөлдөг вэ? Түүний зан чанарын ямар талууд Хуулийн эрин үед илэрхийлэгдсэн бэ? Нигүүлслийн эрин үед аль нь илэрхийлэгдсэн бэ? Тэгээд бас эцсийн эрин үед аль нь илэрхийлэгдсэн бэ? Эдгээр нь та нарын тодорхой ойлгох ёстой мөн чанарын асуултууд юм. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний явцад Бурханы бүх зан чанар илчлэгдсэн. Энэ нь зөвхөн Нигүүлслийн эрин үед ч илчлэгдээгүй, зөвхөн Хуулийн эрин үед ч илчлэгдээгүй, тэр ч бүү хэл зөвхөн эцсийн өдрүүдийн энэ цаг хугацаанд ч илчлэгдээгүй. Эцсийн өдрүүдэд гүйцэтгэдэг ажил нь шүүлт, уур хилэн, гэсгээлтийг төлөөлдөг. Эцсийн өдрүүдэд хийгддэг ажил нь Хуулийн эрин үеийн ажил болон Нигүүлслийн эрин үеийн ажлыг орлож чадахгүй. Гэвч энэ гурван үе шат нь хоорондоо холбогдон нэг болдог бөгөөд бүгдээрээ нэгэн Бурханы ажил юм. Мэдээж энэ ажлын гүйцэтгэл нь тусдаа эрин үеүдэд хуваагддаг. Эцсийн өдрүүдэд хийгддэг ажил бүх зүйлийг төгсгөлд нь аваачдаг; Хуулийн эрин үед хийгдсэн нь эхлэлийн ажил байсан; Нигүүлслийн эрин үед хийгдсэн нь золин авралын ажил байсан. Бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх ажлын үзэгдлүүдийн тухайд бол хэн ч ухаарч, ойлгож чадахгүй бөгөөд эдгээр үзэгдэл нь оньсого хэвээр үлддэг. Эцсийн өдрүүдэд, Хаанчлалын эрин үеийг эхлүүлэхийн

тулд үгийн ажил л хийгддэг боловч энэ нь бүх эрин үеийг төлөөлдөггүй. Эцсийн өдрүүд нь эцсийн өдрүүдээс хэтрэхгүй, Хаанчлалын эрин үеэс хэтрэхгүй бөгөөд Нигүүлслийн эрин үеийг, эсвэл Хуулийн эрин үеийг төлөөлдөггүй. Эцсийн өдрүүдэд ердөө л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх бүх ажил та нарт илчлэгддэг. Энэ бол нууцыг тайлж байгаа хэрэг. Ийм төрлийн нууц нь ямар ч хүний тайлж чадахгүй зүйл юм. Хүн Библийн талаар хэчнээн их ойлгодог байх нь хамаагүй, энэ нь үгээс цаашгүй хэвээр үлддэг, учир нь хүн Библийн мөн чанарыг ойлгодоггүй. Библийг уншихдаа хүн зарим нэг үнэнийг ойлгож, зарим үгийг тайлбарлаж, эсвэл зарим алдартай хэсэг болон бүлгийг багахан ухаж төнхөж болох боловч эдгээр үгэн дотор агуулагддаг утгыг ухан гаргаж хэзээ ч чадахгүй, учир нь хүн Ехова, Есүс хоёрын хийсэн ажлын дүр зургийг биш, үхмэл үгсийг л хардаг бөгөөд энэ ажлын нууцыг тайлах ямар ч аргагүй байдаг. Тиймээс зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний нууц нь хамгийн гүн гүнзгий нуугдсан, хамгийн агуу нууц бөгөөд хүний хувьд бүхэлдээ ойлгошгүй юм. Бурхан Өөрөө л хүнд тайлбарлаж, илчлэхгүй бол хэн ч Бурханы хүслийг шууд ухаарч чадахгүй; эс бөгөөс, хүний хувьд эдгээр зүйл үүрд оньсого хэвээр үлдэж, үүрд битүүмжлэгдсэн нууц хэвээр үлдэнэ. Шашны ертөнц дэх хүмүүсийг хэлэхийн ч хэрэггүй; хэрвээ өнөөдөр та нарт хэлээгүй бол та нар ч бас үүнийг ойлгохгүй байх байсан. Зургаан мянган жилийн энэхүү ажил нь эш үзүүлэгчдийн бүх зөгнөлөөс ч илүү нууцлаг. Энэ нь бүтээлийн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэлх хамгийн агуу нууц бөгөөд эрин үеүдийн туршид байсан эш үзүүлэгчдийн дундаас нэг нь ч үүнийг ухан ойлгож чадаагүй, учир нь энэхүү нууц зөвхөн эцсийн эрин үед л тайлагддаг ба өмнө нь хэзээ ч илчлэгдээгүй билээ. Хэрвээ та нар энэ нууцыг ойлгож чаддаг бол, үүнийг бүхэлд нь хүлээн авч чаддаг бол шашны бүх хүнийг энэ нууц ялан дийлэх болно. Зөвхөн энэ л хамгийн агуу үзэгдэл; энэ нь хүний хамгийн их ойлгохыг хүсэн эрмэлзсэн боловч түүний хувьд бас хамгийн тодорхой бус байсан зүйл юм. Нигүүлслийн эрин үед байх үедээ та нар, Есүсийн хийсэн ажил, Еховагийн хийсэн ажил юу байсныг мэдээгүй. Ехова яагаад хууь тогтоосныг, яагаад Тэр хуулийг мөрдөхийг олон түмнээс шаардсаныг, эсвэл яагаад сүм байгуулах хэрэгтэй байсныг хүмүүс ойлгоогүй бөгөөд израильчуудыг яагаад Египетээс цөл рүү, дараа нь Канаан руу удирдан дагуулсныг хүмүүс бүр ч ойлгоогүй. Өнөөдөр л эдгээр хэрэг явдал илчлэгдсэн юм.

Эцсийн өдрүүд дэх ажил нь гурван үе шатны сүүлчийнх нь юм. Энэ нь өөр нэг шинэ эрин үеийн ажил бөгөөд удирдлагын ажлыг бүхэлд нь төлөөлдөггүй. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нь ажлын гурван үе шатанд хуваагддаг. Аль ч үе шат нь дангаараа гурван эрин үеийн ажлыг төлөөлж чадахгүй, харин нэг хэсгийг нь л төлөөлж чадна. Ехова гэх нэр Бурханы бүх зан чанарыг төлөөлж чадахгүй. Тэрээр Хуулийн эрин үед Өөрийн ажлыг гүйцэтгэсэн гэх баримт нь Бурхан бол хуулийн дор л Бурхан байж чадна гэдгийг баталдаггүй. Ехова хүний төлөө хууль гаргаж, тушаал буулгасан ба сүм болон тахилын ширээ барихыг

хүмүүсээс хүссэн; Түүний хийсэн ажил Хуулийн эрин үеийг л төлөөлдөг. Түүний хийсэн ажил нь Бурхан бол хүнээс хууль мөрдөхийг л шаарддаг Бурхан, эсвэл сүм дэх Бурхан, тахилын ширээний өмнөх Бурхан гэдгийг нотолдоггүй. Ингэж хэлбэл буруу байх болно. Хуулийн доорх ажил нэг эрин үеийг л төлөөлж чадна. Тиймээс хэрвээ Бурхан Хуулийн эрин үеийн ажлыг л хийсэн бол хүн Бурханыг дараах тодорхойлолт дотор хорьж, “Бурхан бол сүм дэх Бурхан бөгөөд Бурханд үйлчлэхийн тулд бид тахилчийн нөмрөг өмсөж, сүмд орох ёстой” хэмээн хэлэх байв. Хэрвээ Нигүүлслийн эрин үеийн ажил хэзээ ч хийгдээгүй ба Хуулийн эрин үе өнөөг хүртэл үргэлжилсэн бол Бурхан бас өршөөнгүй агаад хайр энэрэлтэй гэдгийг хүн мэдэхгүй байх байлаа. Хэрвээ Хуулийн эрин үеийн ажил хийгдээгүй, харин Нигүүлслийн эрин үеийн ажил л хийгдсэн бол Бурхан зөвхөн хүнийг золин аварч, нүглийг нь өршөөж чадна гэдгийг л хүн мэдэх байв. Тэр бол ариун агаад гэм зэмгүй, мөн хүний төлөө Өөрийгөө золиосолж, цовдлогдож чадна гэдгийг л хүн мэдэх байлаа. Хүн эдгээр зүйлийг л мэдэх боловч бусад бүх зүйлийн талаар ямар ч ойлголтгүй байх байсан юм. Тиймээс эрин үе бүр Бурханы зан чанарын нэг хэсгийг төлөөлдөг. Бурханы зан чанарын ямар талыг Хуулийн эрин үе, ямрыг нь Нигүүлслийн эрин үе, ямрыг нь өнөөгийн үе шат төлөөлдгийн тухайд бол: гурван үе шатыг бүгдийг нь нэгэн бүхэл болгон нэгтгэсэн цагт л Бурханы зан чанарыг бүхэлд нь илчилж чадна. Хүн гурван үе шатны ажлыг бүгдийг нь мэдэж авсан цагтаа л үүнийг бүрэн ойлгож чадна. Гурван үе шатны алийг нь ч орхигдуулж болохгүй. Чи ажлын энэ гурван үе шатыг мэдэж авсныхаа дараа л Бурханы зан чанарыг бүхэлд нь харах болно. Бурхан Хуулийн эрин үе дэх ажлаа дуусгасан гэх баримт нь Тэр бол зөвхөн хуулийн доорх Бурхан гэдгийг баталдаггүй бөгөөд Тэр золин авралын ажлаа дуусгасан гэх баримт нь Бурхан үүрд хүн төрөлхтнийг золин аварна гэсэн үг биш. Эдгээр нь бүгд хүний гаргасан дүгнэлт юм. Нигүүлслийн эрин үе дууссан болохоор чи, Бурхан зөвхөн загалмайд харьяалагддаг, загалмай ганцаараа Бурханы авралыг төлөөлдөг гэж хэлж болохгүй. Тэгэх нь Бурханыг хязгаарлаж буй хэрэг. Өнөөгийн үе шатанд Бурхан үндсэндээ үгийн ажил хийж байгаа боловч Бурхан хэзээ ч хүнд өршөөнгүй хандаж байгаагүй, гагцхүү гэсгээлт, шүүлт л авчирдаг гэж чи хэлж болохгүй. Эцсийн өдрүүд дэх ажил нь хүн төрөлхтний хүрэх газар, төгсгөлийг илчилж, хүн төрөлхтний дундах авралын бүх ажлыг төгсгөхийн тулд Ехова, Есүс хоёрын ажлыг болон хүний ойлгодоггүй бүх нууцыг ил болгодог. Эцсийн өдрүүд дэх ажлын энэ үе шат нь бүх зүйлийг дуусгавар болгодог. Эдгээр нууцын гүнд нь орж, зүрх сэтгэлдээ тов тодорхой ойлгох боломжийг хүнд олгохын тулд хүний ойлгоогүй бүх нууцыг дэлгэх ёстой. Тэр үед л хүн төрөлхтнийг төрлийнх нь дагуу ангилж болно. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө дууссаны дараа л хүн Бурханы зан чанарыг бүхэлд нь ойлгож авна, учир нь Түүний удирдлага тэр үед дуусчихсан байх болно. Одоо та нар эцсийн эрин үе дэх Бурханы ажлыг туулсан, тэгвэл Бурханы зан чанар юу вэ? Бурхан бол үг хэлдэг Бурханаас цаашгүй гэж чи хэлж зүрхлэх үү? Чи ийм дүгнэлт хийж зүрхлэхгүй. Бурхан бол

нууцуудыг тайлдаг Бурхан, Бурхан бол Хурга, мөн долоон лацыг эвддэг Нэгэн гэж зарим хүн хэлнэ. Гэхдээ хэн ч ийм дүгнэлт гаргаж зүрхэлдэггүй. Бусад нь Бурхан бол махбод болсон бие гэж хэлж болзошгүй боловч энэ нь мөн л буруу байна. Бас зарим нь бие махбодтой болсон Бурхан зөвхөн үг хэлдэг бөгөөд тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй гэж хэлж магад боловч чи ийм маягаар ярьж бүр ч зүрхлэхгүй, учир нь Есүс махбод болж, тэмдэг гайхамшиг үзүүлсэн, иймээс чи Бурханыг ийм хөнгөхнөөр тодорхойлж зүрхлэхгүй. Зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний туршид хийгдсэн бүх ажил одоо л төгсгөлдөө ирсэн. Энэ бүх ажлыг хүнд илчилж, хүн төрөлхтний дунд гүйцэтгэсний дараа л тэд Бурханы бүх зан чанарыг болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг мэдэх болно. Энэ үе шатны ажил бүрэн дуусахад хүний ойлгодоггүй бүх нууц илчлэгдсэн байх бөгөөд урьд нь ойлгоогүй байсан бүх үнэн ойлгомжтой болж, хүн төрөлхтөнд ирээдүйн зам, хүрэх газрыг нь хэлсэн байх болно. Энэ бол өнөөгийн үе шатанд хийгдэх бүхий л ажил юм. Хэдийгээр хүний өнөөдөр алхдаг зам ч бас загалмайн зам, зовлонгийн зам боловч өнөөдөр хүний хэрэгжүүлж, идэж, ууж, эдэлдэг зүйлс нь хуулийн дор болон Нигүүлслийн эрин үед байсан хүмүүсийнхээс асар өөр билээ. Өнөөдөр хүнээс шаарддаг зүйл өнгөрсөн үеийнхтэй адилгүй бөгөөд Хуулийн эрин үед хүнээс шаардаж байсантай бүр ч адилгүй. Тэгвэл Бурханы Израильд ажлаа хийж байхдаа хуулийн дор байгаа хүнээс юу шаардсан бэ? Энэ нь, хүн Амралтын өдрийг болон Еховагийн хуулийг мөрдөх ёстой гэдгээс хэтрээгүй. Хэн ч Амралтын өдрөөр ажиллаж, эсвэл Еховагийн хуулийг зөрчиж болохгүй байв. Гэхдээ одоо тийм биш. Амралтын өдөр хүн ердийнхөөрөө ажиллаж, цугларч, залбирдаг ба хүнд ямар ч хориг хязгаарлалт тавьдаггүй. Нигүүлслийн эрин үеийн хүмүүс баптисм хүртэх хэрэгтэй байсан, улмаар мацаг барьж, талх хугалж, дарс ууж, толгойгоо бүтээж, хөлөө угаахыг тэднээс шаардсан. Одоо энэ дүрмүүд хүчингүй болсон боловч хүнд бүр ч их шаардлага тавьдаг, учир нь Бурханы ажил улам бүр гүнзгийрч, хүний оролт улам өндөрсөж байдаг. Урьд нь Есүс хүн дээр гараа тавин залбирсан, харин одоо бүхнийг хэлсэн болохоор гараа тавихын хэрэг юу байх билээ? Дан ганц үгээр үр дүнд хүрч болно. Урьд нь Тэрээр хүн дээр гараа тавих үед энэ нь хүнийг ерөөж, бас өвчнийг нь эдгээх зорилготой байлаа. Тухайн үед Ариун Сүнс ингэж ажилладаг байсан, гэхдээ одоо тийм биш. Одоо Ариун Сүнс ажиллаж, үр дүнд хүрэхийн тулд үг ашигладаг. Түүний үг та нарт тодорхой болсон бөгөөд та нар хэлсний дагуу хэрэгжүүлэх ёстой. Түүний үг бол Түүний хүсэл; тэдгээр нь Түүний хийхийг хүсдэг ажил. Үгээр нь дамжуулан чи Түүний хүслийг ойлгож, юунд хүрэхийг чамаас шаардаж байгааг ойлгоно, мөн гар тавих ямар ч хэрэггүйгээр Түүний үгийг шууд хэрэгжүүлж болно. Зарим хүн: “Гараа над дээр тавиач! Гараа над дээр тавивал би Таны ерөөлийг хүртэж, Танаас хуваалцаж болох юм” гэж хэлж болзошгүй. Энэ бүхэн нь өнгөрсөн үеийн хоцрогдсон хэрэгжүүлэлт бөгөөд эрин үе солигдсон учраас одоо хэрэглэхээ больсон. Ариун Сүнс санамсаргүй байдлаар ч биш, эсвэл тогтсон дүрмийн дагуу ч биш, харин эрин үед нийцүүлэн ажилладаг. Эрин үе

өөрчлөгдсөн бөгөөд шинэ эрин үе шинэ ажлыг зайлшгүй авчирдаг. Ажлын үе шат бүр ийм байдаг тул Түүний ажил хэзээ ч давтагддаггүй. Нигүүлслийн эрин үед Есүс өвчнийг эдгээж, чөтгөрийг хөөх, хүний төлөө залбирахын тулд гараа хүн дээр тавих, хүнийг ерөөх гэх зэрэг ажлыг хангалттай хэмжээнд хийсэн. Гэвч өнөө үед үүнийг дахин хийх нь утга учиргүй байх байв. Ариун Сүнс тухайн үед тийм маягаар ажилласан, учир нь энэ нь Нигүүлслийн эрин үе байсан ба хүний эдлэх нигүүлсэл хангалттай байлаа. Хүнээс ямар ч төлөөс төлөхийг шаардаагүй бөгөөд итгэлтэй байх л юм бол нигүүлсэл хүртэх байв. Бүгдэд маш нигүүлсэнгүйгээр хандаж байсан юм. Одоо эрин үе өөрчлөгдсөн бөгөөд Бурханы ажил цааш улам ахисан; гэсгээлт, шүүлтээр дамжуулан хүний тэрслүү байдлыг болон доторх бохир зүйлсийг нь арилгана. Тэр үе шат золин авралын үе шат байсан болохоор Бурхан тийм маягаар ажиллаж, эдлэх хангалттай нигүүлслийг хүнд харуулах ёстой байв, ингэснээр хүнийг нүглээс золин аварч, нигүүлслээр дамжуулан нүглийг нь уучилж болох байлаа. Өнөөгийн энэ үе шат нь хүмүүсийг дараа нь аврахын тулд гэсгээлт, шүүлт, үгийн цохилт, түүнчлэн үгийн сахилгажуулалт болон илчлэлийн аргаар хүний доторх шударга бус байдлыг ил болгодог. Энэ бол золин авралаас ч илүү гүнзгий ажил билээ. Нигүүлслийн эрин үе дэх нигүүлсэл нь хүн эдлэхэд хангалттай байсан; одоо хүн энэ нигүүлслийг аль хэдийн мэдэрсэн болохоор цаашид дахиж эдлэхгүй. Энэ ажил одоо үеэ өнгөрөөсөн ба цаашид дахиж хийгдэхгүй. Одоо хүнийг үгийн шүүлтээр дамжуулан аварна. Хүнийг шүүж, гэсгээж цэвэршүүлсний дараа зан чанар нь өөрчлөгддөг. Энэ нь бүгд Миний хэлсэн үгээс болдоггүй гэж үү? Ажлын үе шат бүр нь бүх хүн төрөлхтний ахиц дэвшил болон эрин үеийн дагуу хийгддэг. Ажил бүхэлдээ ач холбогдолтой байдаг, энэ бүхэн нь эцсийн авралын төлөө, хүн төрөлхтөн ирээдүйд сайн сайхан хүрэх газартай байхын төлөө, эцэст нь хүмүүс төрлөөрөө ангилагдахын төлөө хийгддэг.

Эцсийн өдрүүдийн ажил бол үг хэлэх явдал юм. Үгийн тусламжтайгаар хүнд асар их өөрчлөлт гарч болно. Эдгээр үгийг хүлээн зөвшөөрснөөр өнөөгийн хүмүүст гарч байгаа өөрчлөлтүүд нь Нигүүлслийн эрин үеийн тэмдэг, гайхамшгийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийнхээс хамаагүй их. Учир нь Нигүүлслийн эрин үед гараа дээр нь тавьж, залбирснаар хүнээс чөтгөрүүдийг хөөн зайлуулж байсан боловч хүний доторх завхарсан зан чанар хэвээр үлдсэн юм. Хүний өвчнийг эдгээж, нүглийг нь өршөөсөн боловч хүний доторх завхарсан сатанлаг зан чанарыг яг яаж арилгах тухайд бол энэ ажил хараахан хийгдээгүй. Хүн итгэлээсээ үүдэн аврагдаж, нүглээ уучлуулсан боловч хүний нүгэлт уг чанар арилаагүй бөгөөд дотор нь үлдсэн юм. Бие махбодтой болсон Бурханы тусламжтайгаар хүний нүглийг уучилсан боловч хүний дотор нүгэл байхаа больсон гэсэн үг биш. Нүглийн тахилаар дамжуулан хүний нүглийг өршөөж болох боловч хүний нүгэл үйлдэхийг яг яаж болиулах, нүгэлт уг чанарыг нь яаж бүрэн арилгаж, өөрчлөх тухайд бол хүн энэ асуудлыг шийдвэрлэх ямар ч аргагүй байдаг. Хүний нүглийг өршөөсөн нь Бурханы цовдлолын ажлаас үүдсэн боловч хүн хуучны, завхарсан сатанлаг зан чанар

дотроо үргэлжлүүлэн амьдарсаар юм. Ийм болохоор хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн аврах ёстой, ингэснээр түүний нүгэлт уг чанар дахин хэзээ ч хөгжихгүйгээр бүрэн арилж, улмаар хүний зан чанар өөрчлөгдөх боломжтой болох юм. Энэ нь амийн өсөлтийн замыг, амийн замыг болон зан чанараа өөрчлөх замыг ухаарахыг хүнээс шаарддаг. Түүнчлэн, энэ замын дагуу хэрэгжүүлж, зан чанараа аажмаар өөрчилж, гэрлийн гялбаан дор амьдарч, хийдэг бүхнээ Бурханы хүслийн дагуу байлгаж, завхарсан сатанлаг зан чанараа хаяж, Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижирч, улмаар нүглээс бүрэн ангижрахыг хүнээс шаарддаг. Тэгсэн цагт л хүн бүрэн аврал хүртэнэ. Есүсийг ажлаа хийж байх үед Түүний талаарх хүний мэдлэг мөн л бүдэг бадаг, тодорхойгүй байв. Тэр бол Давидын хүү гэдэгт хүн үргэлж итгэж байсан ба Тэр бол агуу эш үзүүлэгч, хүний нүглийг золин аварсан энэрэнгүй Эзэн хэмээн тунхагласан юм. Итгэлийнхээ хүчээр зарим нь Түүний хувцасны заханд хүрэх төдийд эдгэж, сохор хүн харж, үхсэн хүн ч дахин амилж байлаа. Гэвч хүн өөрийнх нь дотор гүн үндэслэсэн завхарсан сатанлаг зан чанарыг олж мэдэж чадаагүй, үүнийг хэрхэн хаяхыг ч мэдээгүй. Хүн махан биеийн амар амгалан, аз жаргал, нэг гишүүнийх нь итгэл бүхий л гэр бүлийнхэнд ерөөл авчрах, өвчнийг эдгээх гэх мэт ихээхэн нигүүлслийг хүлээн авчээ. Үлдсэн нь хүний сайн үйл хэрэг, мөн түүний сүсэг бишрэлтэй төрх байдал байв; хэрвээ хүн эдгээрт үндэслэн амьдарч чаддаг бол түүнийг боломжийн итгэгч гэж үздэг байлаа. Ийм итгэгчид л үхсэнийхээ дараа диваажинд орж чадах байсан ба энэ нь тэд аврагдсан гэсэн үг байлаа. Гэвч энэ хүмүүс амьдрах хугацаандаа амийн замыг огт ойлгоогүй юм. Тэд зан чанараа өөрчлөх ямар ч замгүйгээр тогтмол давтамжтайгаар нүгэл үйлдэж, дараа нь нүглээ улайдаг байсан: Нигүүлслийн эрин үе дэх хүний нөхцөл байдал ийм байлаа. Хүн бүрэн аврал хүртсэн үү? Үгүй! Тиймээс ажлын тэрхүү үе шат дууссаны дараа шүүлт, гэсгээлтийн ажил хэвээр үлдсэн юм. Энэ үе шат нь үгийн тусламжтайгаар хүнийг ариусгаж, улмаар түүнд дагах зам өгөхийн төлөө байдаг. Хэрвээ чөтгөрийг хөөн зайлуулахаа үргэлжлүүлсээр байсан бол энэ үе шат үр дүнгүй, утга учиргүй байх байлаа, учир нь энэ нь хүний нүгэлт уг чанарыг арилгаж чадахгүй бөгөөд хүн нүглээ уучлуулаад л зогсонги байдалд орох байв. Цовдлолын ажил аль хэдийн дуусаж, Бурхан Сатаныг ялан дийлсэн учраас нүглийн тахилаар дамжуулан хүн нүглээ уучлуулсан. Гэвч хүний доторх завхарсан зан чанар хэвээр үлдэж, хүн нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэж мөн л чаддаг бөгөөд Бурхан хүн төрөлхтнийг олж аваагүй. Тиймээс ажлын энэ үе шатанд Бурхан хүний завхарсан зан чанарыг илчлэхдээ үг ашиглаж, зөв замын дагуу хэрэгжүүлэхэд түүнийг хүргэдэг. Энэ үе шат нь өмнөхийг бодвол илүү утга учиртай, мөн түүнчлэн илүү үр дүнтэй байдаг, учир нь одоо цагт хүний амийг шууд хангаж, хүний зан чанарыг бүрэн шинэчлэхэд хүргэдэг зүйл нь үг билээ; энэ нь ажлын илүү бүрэн гүйцэд үе шат юм. Тиймээс эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан нь Бурхан бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцээж, хүнийг аврах Бурханы удирдлагын төлөвлөгөөг бүрэн дуусгасан юм.

Бурхан хүнийг аврахдаа Сүнсний арга барил, Сүнсний ялгамж чанарыг шууд ашиглан хийдэггүй, учир нь хүн Түүний Сүнсэнд хүрч чадахгүй, харж чадахгүй, мөн ойртож ч чадахгүй. Хэрвээ Тэр Сүнс байдлаар хүнийг шууд аврахаар оролдсон бол хүн Түүний авралыг хүртэж чадахгүй байх байлаа. Хэрвээ Бурхан бүтээгдсэн хүний гадаад хэлбэртэй болоогүй бол хүний хувьд энэ авралыг хүртэх ямар ч аргагүй байх байв. Учир нь хэн ч Еховагийн үүлэнд дөхөн очиж хүн Түүнд ойртох ямар ч аргагүй байдаг. Зөвхөн бүтээгдсэн хүн болсноор, өөрөөр хэлбэл, Өөрийн болох гэж буй махбодод үгээ оруулснаар л Тэр Өөрийг нь дагадаг бүх хүнд үгийг биечлэн оруулж чадна. Тэр үед л хүн өөрийн биеэр Түүний үгийг харж, сонсож, түүнчлэн Түүний үгийг эзэмшиж, үүгээр дамжуулан бүрэн аврагдаж чадна. Хэрвээ Бурхан махбод болоогүй бол мах цуснаас бүтсэн нэг ч хүн ийм агуу авралыг хүртэж чадахгүй байсан бөгөөд ганц ч хүн аврагдахгүй байх байлаа. Хэрвээ Бурханы Сүнс шууд хүн төрөлхтний дунд ажилласан бол бүх хүн цохиулж, эсвэл Бурхантай холбогдох ямар ч аргагүйн улмаас Сатанд бүрмөсөн олзлогдох байв. Эхний удаа бие махбодтой болсон нь хүнийг нүглээс золин аварсан ба Есүсийн бие махбодын тусламжтайгаар хүнийг золин аварсан юм. Өөрөөр хэлбэл, Тэр хүнийг загалмайнаас аварсан боловч хүний дотор завхарсан сатанлаг зан чанар мөн л үлджээ. Хоёр дахь удаа бие махбодтой болсон нь дахиж нүглийн тахил болж үйлчлэхгүй, харин ч нүглээс золин аврагдсан хүмүүсийг бүрэн аврахын төлөө байдаг. Энэ нь уучлагдсан хүмүүсийг нүглээс нь гэтэлгэж, бүрэн ариусгаж, мөн зан чанарын өөрчлөлтөд хүргэснээр Сатаны харанхуй нөлөөнөөс ангижруулж, Бурханы сэнтийн өмнө буцаан авчрахын тулд хийгддэг. Ийм маягаар л хүн бүрэн ариусаж чадна. Хуулийн эрин үе дууссаны дараа Нигүүлслийн эрин үе эхлэхийн хамтаар Бурхан авралын ажлыг эхлүүлсэн ба энэ нь эцсийн өдрүүдэд хүн төрөлхтний тэрслүү байдлыг шүүж, гэсгээж, тэднийг бүрмөсөн ариусгах хүртэл үргэлжилдэг. Дараа нь л Бурхан авралын ажлаа төгсгөөд амралтад орно. Тиймээс ажлын гурван үе шатанд Өөрийн ажлыг хүмүүсийн дунд биечлэн гүйцэтгэхийн тулд Бурхан хоёр удаа л махбод болсон юм. Яагаад гэвэл, ажлын гурван үе шатны ердөө нэг нь л хүмүүсийн амьдралыг залж чиглүүлэх явдал байсан, харин нөгөө хоёр нь авралын ажлаас бүрддэг. Бурхан махбод болсноор л хүмүүстэй хамт амьдарч, дэлхий ертөнцийн зовлонг туулж, хэвийн махан биед амьдарч чадна. Зөвхөн ийм маягаар л Тэр, бүтээгдсэн зүйлийн хувиар хүмүүст хэрэгтэй байдаг бодитой үгээр хүмүүсийг хангаж чадна. Хүн бие махбодтой болсон Бурханаар дамжуулан Бурханаас бүрэн аврал хүртдэг болохоос биш, залбирлынхаа хариуд тэнгэрээс шууд хүртдэггүй. Хүн мах, цуснаас бүрдсэн учраас Бурханы Сүнсэнд ойртох нь бүү хэл, Түүний Сүнсийг харах ямар ч аргагүй байдаг. Хүн Бурханы махбод болсон биетэй л харилцаж чадах бөгөөд үүгээр л дамжуулан бүх зам, бүх үнэнийг ойлгож, бүрэн авралыг хүлээн авч чадна. Хоёр дахь удаа бие махбодтой болох нь хүний нүглийг арилгаж, хүнийг бүрэн ариусгахад хангалттай байх болно. Иймд хоёр дахь удаа бие махбодтой болоход махбод дахь Бурханы бүх ажил

төгсөж, Бурхан бие махбодтой болохын ач холбогдол бүрэн гүйцэд болно. Энэ үеэс махбод дахь Бурханы ажил бүхэлдээ дууссан байх болно. Хоёр дахь удаа бие махбодтой болсныхоо дараа Тэр гурав дахь удаа бие махбодтой болох ажлыг хийхгүй. Учир нь Түүний удирдлага бүхэлдээ төгсчихсөн байна. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан Өөрийн сонгосон хүмүүсийг бүрэн олж авсан байх ба эцсийн өдрүүд дэх хүмүүс бүгд төрлөөрөө ангилагдсан байх болно. Тэр авралын ажлыг дахин хийхгүй, мөн ямар нэг ажил хийхийн тулд махбодод ч эргэн ирэхгүй. Эцсийн өдрүүдийн ажилд үг нь тэмдэг, гайхамшгийн илрэлээс илүү сүр хүчтэй байдаг бөгөөд үгийн эрх мэдэл нь тэмдэг, гайхамшгийнхаас давдаг. Үг нь хүний зүрх сэтгэлийн гүнд булагдсан бүх ялзарсан зан чанарыг ил болгодог. Чи тэдгээрийг өөрөө таних ямар ч аргагүй. Үгээр дамжуулан тэдгээрийг өмнө чинь ил болгоход чи аяндаа олж мэднэ; чи тэдгээрийг үгүйсгэж чадахгүй бөгөөд бүрэн үнэмшинэ. Энэ нь үгийн эрх мэдэл биш гэж үү? Энэ бол өнөөдрийн үгийн ажлаар хүрсэн үр дүн юм. Тиймээс өвчнийг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулснаар хүнийг нүглээс бүрэн аварч чадахгүй, мөн тэмдэг, гайхамшиг үзүүлснээр дамжуулан бүрэн төгс болгож ч чадахгүй. Өвчнийг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулах эрх мэдэл нь хүнд нигүүлсэл л өгдөг боловч хүний махан бие Сатанд харьяалагдсаар байдаг ба завхарсан сатанлаг зан чанар хүний дотор байсаар байдаг. Өөрөөр хэлбэл, цэвэр болгоогүй зүйл нүгэл болон бузарт хамаатай хэвээр байдаг. Үгийн тусламжтайгаар цэвэр болгуулсны дараа л хүн Бурханаар авхуулж, ариусаж чаддаг. Хүнээс чөтгөрүүдийг хөөн зайлуулж, түүнийг золин аврах үед энэ нь, түүнийг Сатаны гараас булаан авч, Бурханд буцааж өгсөн гэсэн утгатай байв. Гэвч тэр Бурханаар ариусгагдаж, өөрчлөгдөөгүй учраас завхарсан хүн хэвээр үлддэг. Хүний дотор бузар буртаг, эсэргүүцэл, тэрслүү байдал оршсоор байдаг; хүн зөвхөн Бурханы золин авралаар дамжуулж Түүн рүү буцаж очсон боловч Бурханы тухай өчүүхэн төдий ч мэдлэггүй байдаг бөгөөд Түүнийг эсэргүүцэж, Түүнээс урваж мөн л чаддаг. Хүнийг золин аврахаас өмнө Сатаны олон хор аль хэдийн түүний дотор суучихсан бөгөөд Сатанаар олон мянган жил завхруулагдсаны дараа хүний дотор Бурханыг эсэргүүцэх уг чанар тогтсон байдаг. Тиймээс хүнийг золин аврах нь хүнийг өндөр үнээр буцаан авсан золин авралаас цаашгүй байсан боловч хүний доторх хорт чанарыг таягдан хаяагүй юм. Ингэж их бузартсан хүн Бурханд үйлчлэхүйц болохоосоо өмнө өөрчлөгдөх ёстой. Шүүлт, гэсгээлтийн энэ ажлаар дамжуулан өөрийнхөө доторх бохир, завхарсан мөн чанарын талаар хүн бүрэн мэдэж авах бөгөөд бүрэн өөрчлөгдөж, цэвэр болж чадна. Ийм маягаар л хүн Бурханы сэнтийн өмнө буцан очих үнэ цэнтэй болж чадна. Өнөөдөр хийгдэж байгаа бүх ажил нь хүнийг цэвэрлэж, өөрчлөхийн төлөө байдаг; үгийн шүүлт, гэсгээлт, мөн цэвэршүүлэлтээр дамжуулан хүн завхралаа хаяж, ариусгагдаж чадна. Ажлын энэ үе шатыг авралын ажил гэж үзэхээс илүүгээр ариусгалтын ажил гэж нэрлэх нь илүү тохиромжтой. Үнэндээ энэ үе шат нь байлдан дагуулалтын шат, мөн түүнчлэн авралын ажлын хоёр дахь үе шат юм. Үгийн шүүлт, гэсгээлтээр дамжуулан хүнийг

Бурхан олж авдаг; цэвэршүүлж, шүүж, ил болгоход үгийг ашигласнаар хүний зүрх сэтгэлийн доторх хольц, үзэл, сэдэл, хувийн хүсэл эрмэлзэл бүгд бүрэн илчлэгддэг. Хүнийг золин аварч, нүглийг нь уучилсан тухайд бол, Бурхан хүний гэм бурууг санадаггүй, гэм буруугийнх нь дагуу хүнд ханддаггүй гэж л авч үзэж болох юм. Гэвч махан биед амьдардаг хүн нүглээс ангижраагүй бол үргэлжлүүлэн нүгэл үйлдэж, завхарсан сатанлаг зан чанараа эцэс төгсгөлгүй илчилж л чадна. Энэ бол хүний амьдардаг, нүгэл үйлдэж, нүглээ уучлуулдаг эцэс төгсгөлгүй орчлын амьдрал юм. Хүн төрөлхтний ихэнх нь өдөр нь нүгэл үйлдээд орой нь нүглээ улайдаг. Ийм маягаар нүглийн тахил хүний хувьд үүрд хүчинтэй байдаг ч энэ нь хүнийг нүглээс аварч чадахгүй. Хүн завхарсан зан чанартай байсаар байгаа тул авралын ажлын хагас нь л гүйцэлдсэн. Тухайлбал, хүмүүс Моабын үр удам гэдгээ ухаарах үедээ гомдлын үг хэлж, амийг эрэлхийлэхээ больж, туйлын сөрөг болдог. Хүмүүс Бурханы ноёрхол дор бүрэн захирагдаж чадахгүй байсаар байгааг энэ нь харуулдаггүй гэж үү? Энэ нь яг нарийндаа завхарсан сатанлаг зан чанар биш гэж үү? Гэсгээлтэд өртөөгүй байх үедээ чи гараа бусдынхаас, бүр Есүсийнхээс ч илүү өндөрт өргөж байсан. Тэгээд чи чанга дуугаар ийнхүү хашхирсан: “Бурханы хайртай хүү болно! Бурханы дотнын хүн болно! Сатанд сөгдөхийн оронд бид үхэхийг илүүд үзнэ! Хөгшин Сатаны эсрэг босоцгоо! Агуу улаан лууны эсрэг босоцгоо! Агуу улаан луу арчаагүйгээр эрх мэдлээ алдах болтугай! Бурхан биднийг бүрэн төгс болгох болтугай!” Хашхираан чинь бусад бүх хүнийхээс ч илүү чанга байсан. Харин дараа нь гэсгээлтийн цаг үе ирэхэд хүмүүсийн завхарсан зан чанар дахин нэгэнтээ илчлэгдсэн юм. Тэгээд тэдний хашхираан намжиж, шийдэмгий байдал нь бүтэлгүйтсэн. Энэ бол хүний завхрал; нүглээс илүү гүн нэвчсэн энэ нь Сатаны суулгасан, хүний дотор гүнзгий үндэслэсэн зүйл юм. Хүн өөрийнхөө нүглийг мэддэг болох нь маш амаргүй; тэр өөрийнх нь дотор гүнзгий үндэслэсэн уг чанарыг таних ямар ч аргагүй байдаг бөгөөд энэ үр дүнд хүрэхийн тулд үгийн шүүлтэд найдах ёстой. Тэгж байж л хүн энэ үеэс эхлэн аажмаар өөрчлөгдөж чадна. Хүн төрөлхийн завхарсан зан чанараа огт ойлгодоггүй байсан учраас өмнө нь тэгж хашхирсан юм. Энэ нь хүний дотор оршдог бохир хольц билээ. Тийм удаан хугацааны шүүлт, гэсгээлтийн хугацаанд хүн түгшүүртэй орчинд амьдарсан. Энэ бүхэн нь үгийн тусламжтайгаар хийгдээгүй гэж үү? Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтаас өмнө чи ч бас маш чанга дуугаар хашхираагүй гэж үү? “Хаанчлалд орлоо! Энэ нэрийг хүлээн зөвшөөрдөг бүхэн хаанчлалд орно! Бүгд Бурхантай хуваалцана!” Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт ирэхэд чи хашхирахаа больсон. Эхэндээ бүгд: “Өө Бурхан минь! Та намайг хаана ч тавьсан, би Таны жолоодлогод захирагдана” гэж хашхирсан. “Хэн Миний Паул байх вэ?” хэмээх Бурханы үгийг уншаад хүмүүс “Би бэлэн!” гэцгээсэн. Тэгээд тэд “Иовын итгэл ямар вэ?” хэмээх үгийг харсан ба “Би Иовын итгэлийг авахад бэлэн байна. Бурхан минь, туршилтад оруулаач!” гэсэн юм. Үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт ирэх үед тэд дорхноо нуран унаад, дахин босож чадахгүй байх шахсан. Түүний дараа тэдний зүрх сэтгэл дэх

хольц яваандаа багассан. Энэ нь үгээр хийгдээгүй гэж үү? Иймээс өнөөдөр та нарын туулсан зүйл бол үгээр дамжин хүрсэн үр дүн бөгөөд Есүсийн үзүүлсэн тэмдэг, гайхамшгуудын хүрсэн үр дүнгээс ч илүү агуу юм. Чиний хардаг Бурханы алдар болон Бурханы Өөрийн эрх мэдэл нь ердөө цовдлолын тусламжтайгаар, мөн өвчнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулснаар харагддаг юм биш, харин Түүний үгийн шүүлтээр дамжуулан бүр ч их харагддаг. Бурханы эрх мэдэл, хүч чадал нь зөвхөн тэмдэг үзүүлж, өвчнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулахаас бүрддэг юм биш, харин Бурханы үгийн шүүлт нь Бурханы эрх мэдлийг илүү сайн төлөөлж, Түүний төгс хүчнийг илүү сайн илчилж чаддаг гэдгийг энэ нь харуулдаг.

Хүний одоо хүрсэн зүйл—түүний өнөөгийн биеийн хэмжээ, мэдлэг, хайр, үнэнч зан, дуулгавартай байдал, мэдлэг ухаан—эдгээр нь үгийн шүүлтээр хүрсэн үр дүн юм. Үгийн тусламжтайгаар чи үнэнч байж, өнөөг хүртэл зогссон хэвээр байж чаддаг. Одоо хүн бие махбодтой болсон Бурханы ажил нь үнэхээр ер бусын гэдгийг хардаг бөгөөд үүнд хүний хүрч чадахгүй олон зүйл байдаг, тэдгээр нь нууц болон гайхамшгууд юм. Тиймээс олон хүн захирагдсан. Зарим нь төрснөөсөө хойш хэнд ч, хэзээ ч захирагдаж байгаагүй мөртөө Бурханы өнөөдрийн үгийг харах үедээ өөрийн мэдэлгүй бүрэн захирагддаг бөгөөд үүнийг судалж, эсвэл өөр юм хэлж зүрхэлдэггүй. Хүмүүс үгэн дор унаж, үгийн шүүлт дор нүүрээрээ газар унан мөргөсөн. Хэрэв Бурханы Сүнс хүнтэй шууд ярьсан бол хүн төрөлхтөн бүгд дуу хоолойд захирагдаж, Дамаск явах замдаа Паул гэрэл дунд газар унасантай яг адилаар хүмүүс бүгд илчлэлийн үггүйгээр доош унах байсан юм. Хэрвээ Бурхан ийм маягаар үргэлжлүүлэн ажилласан бол хүн үгийн шүүлтээр дамжуулан өөрийн завхралыг хэзээ ч мэдэж авч чадахгүй, улмаар аврал хүртэхгүй байх байв. Зөвхөн махбод болсноор л Бурхан Өөрийн үгийг хүн нэг бүрийн чихэнд биечлэн хүргэж чадна, ингэснээр чихтэй бүхэн Түүний үгийг сонсож, Түүний үгийн шүүлтийн ажлыг хүлээн авч болох юм. Энэ нь л Түүний үгийн хүрдэг үр дүн болохоос биш, Сүнс илэрч, хүнийг айлган эрхшээлдээ оруулдаг юм биш. Зөвхөн ийм бодит атлаа ер бусын ажлаар дамжуулан хүний дотор олон жил гүн нуугдсан хуучин зан чанар бүрэн ил болдог, ингэснээр хүн үүнийг таньж, өөрчилж болох юм. Эдгээр нь бүгд бие махбодтой болсон Бурханы бодитой ажил бөгөөд бодитой байдлаар ярьж, шүүлт явуулснаар Тэр үгээр хүнийг шүүх үр дүнд хүрдэг. Энэ бол бие махбодтой болсон Бурханы эрх мэдэл бөгөөд Бурхан бие махбодтой болохын ач холбогдол билээ. Бие махбодтой болсон Бурханы эрх мэдлийг ил болгохын тулд, үгийн ажлаар хүрсэн үр дүнг ил болгож, Сүнс махбодод ирчихсэн ба хүнийг үгээр шүүснээр дамжуулан эрх мэдлээ харуулж байгааг ил болгох гэж үүнийг хийдэг. Түүний махбод хэдийгээр жирийн, хэвийн хүн чанарын гадаад хэлбэртэй боловч Түүний үгийн хүрдэг үр дүн нь Тэр бол эрх мэдлээр дүүрэн, Тэр бол Бурхан Өөрөө, Түүний үг бол Бурханы Өөрийн илэрхийлэл гэдгийг хүнд харуулдаг. Энэ аргаар Тэр бол Бурхан Өөрөө, Тэр бол махбод болсон Бурхан Өөрөө, Түүнд хэн ч халдаж болохгүй, Түүний үгийн шүүлтийг хэн ч давж чадахгүй, мөн ямар ч харанхуйн хүч

Түүний эрх мэдлийг дийлж чадахгүй гэдгийг бүх хүнд харуулдаг. Тэр бол Үг болсон махбод учраас, мөн Түүний эрх мэдлээс болж, Түүний үгийн шүүлтээс болж хүн Түүнд захирагддаг. Бурханы махбод болсон биеийн авчирсан ажил нь Түүний эзэмшдэг эрх мэдэл билээ. Махбод ч гэсэн эрх мэдэл эзэмшдэг учраас Тэр махбод болсон бөгөөд хүн төрөлхтний дунд бодитой байдлаар ажиллаж чаддаг, ийм маягаар хүн харж, хүрч болдог. Энэ ажил нь, бүх эрх мэдлийг эзэмшдэг Бурханы Сүнсний шууд хийдэг ажлаас илүү бодитой, үр дүн нь ч бас илэрхий байдаг. Яагаад гэвэл, Бурханы махбод болсон бие бодитоор ярьж, ажиллаж чаддаг. Түүний махбодын гадаад хэлбэр төрх ямар ч эрх мэдэл агуулдаггүй бөгөөд хүн ойртож болдог байхад Түүний мөн чанар эрх мэдлийг агуулдаг, гэхдээ эрх мэдэл нь хэнд ч харагддаггүй. Түүнийг ярьж, ажиллаж байх үед хүн Түүнд эрх мэдэл байгааг олж илрүүлж чаддаггүй; энэ нь Түүний бодитой ажилд нэмэр болдог. Энэ бүх бодитой ажил үр дүнд хүрч чадна. Хэн ч Түүнд эрх мэдэл байгааг ухаардаггүй, халдашгүй гэдгийг нь хардаггүй, эсвэл Түүний уур хилэнг хардаггүй боловч далдлагдсан эрх мэдэл, нуугдмал уур хилэн болон ил тод хэлдэг үгээрээ дамжуулан Тэр Өөрийн үгийн зорьсон үр дүнд хүрдэг. Өөрөөр хэлбэл, Өөрийн дуу хоолойн өнгө, ярианы хатуу чанга байдал, Өөрийн үгийн бүх мэргэн ухаанаар дамжуулан хүнийг бүрэн үнэмшүүлдэг. Ийм маягаар харваас ямар ч эрх мэдэлгүй, бие махбодтой болсон Бурханы үгэнд хүн захирагдаж, улмаар хүнийг аврах Бурханы зорилго биелдэг. Илүү бодитоор ярьж, үгийнх нь бодит байдал хүнд үр нөлөө үзүүлэх боломж олгож, хүнд Бурханы үгийн хүч чадлыг харуулах нь Бурхан бие махбодтой болсны ач холбогдлын өөр нэг тал юм. Тиймээс энэ ажлыг бие махбодтой болсноор дамжуулан хийхгүй бол өчүүхэн төдий ч үр дүнд хүрэхгүй бөгөөд нүгэлт хүмүүсийг бүрэн аварч чадахгүй байх байлаа. Хэрвээ Бурхан махбод болоогүй бол хүнд үзэгдэшгүй, баригдашгүй Сүнс хэвээр үлдэх байв. Хүн махан биетэй бүтээл тул Бурхан, хүн хоёр өөр өөр ертөнцөд харьяалагддаг бөгөөд өөр өөр шинж чанартай байдаг. Бурханы Сүнс махан биетэй хүнтэй огт нийцдэггүй, тэдний хооронд харилцаа тогтоох ямар ч аргагүй бөгөөд хүн сүнс болох чадваргүйг дурдахын ч хэрэггүй. Ийм болохоор Өөрийн анхдагч ажлыг хийхийн тулд Бурханы Сүнс бүтээгдсэн зүйл болох ёстой. Бурхан хамгийн өндөр газарт гарч чадахын сацуу Өөрийгөө даруу болгон бүтээгдсэн хүн болж, хүн төрөлхтний дунд ажиллаж, тэдний дунд амьдарч чаддаг, харин хүн өндөрт гарч, сүнс болж чадахгүй, хамгийн доод газарт буун очиж бүр ч чадахгүй. Ийм учраас Бурхан Өөрийн ажлыг гүйцэтгэхийн тулд махбод болох ёстой. Тэрчлэн, эхний удаа бие махбодтой болох үеэр бие махбодтой болсон Бурханы махбод л цовдлолоор дамжуулан хүнийг золин аварч чадсан, харин Бурханы Сүнсний хувьд хүний төлөө нүглийн тахил болон цовдлогдох ямар ч аргагүй байв. Хүний төлөөх нүглийн тахил болохын тулд Бурхан шууд махбод болж чаддаг боловч хүн шууд тэнгэрт гарч, өөрийнх нь төлөө Бурханы бэлтгэсэн нүглийн тахилыг авч чадахгүй. Ийм болохоор энэ авралыг авахын тулд хүнийг тэнгэр лүү гаргалгүйгээр, тэнгэр, газрын хооронд хэд хэдэн удаа нааш цааш

явахыг Бурханаас гуйх нь л боломжтой байв, учир нь хүн унаж доройтсон бөгөөд нүглийн тахилыг олж авах нь бүү хэл, тэнгэр өөд гарч ч ер чадахгүй. Тиймээс Есүс хүн төрөлхтний дунд ирж, хүний ердөө хийж чадахгүй ажлыг биечлэн хийх хэрэгтэй байлаа. Бурхан махбод болох бүрд энэ нь зайлшгүй шаардлагатай байдаг. Хэрвээ эдгээр үе шатны аль нэгийг Бурханы Сүнс шууд хийж чадах байсан бол Тэр бие махбодтой болохын доромжлолд өртөхгүй байх байлаа.

Ажлын энэ эцсийн үе шатанд үгээр дамжуулан үр дүнд хүрдэг. Үгээр дамжуулан хүн олон нууцыг болон өнгөрсөн үеүдийн туршид Бурханы хийсэн ажлын талаар ойлгож авдаг; үгээр дамжуулан хүнийг Ариун Сүнс гэгээрүүлдэг; үгээр дамжуулан хүн өмнөх үеийнхний хэзээ ч тайлаагүй нууцуудыг, мөн түүнчлэн өнгөрсөн үеийн эш үзүүлэгч, элч нарын ажлыг, тэдний ажилласан зарчмыг ойлгож авдаг; үгээр дамжуулан хүн бас Бурханы Өөрийн зан чанарыг болон хүний тэрслүү байдал, эсэргүүцлийг ойлгож, өөрийнхөө мөн чанарыг мэдэж авдаг. Ажлын эдгээр алхам болон хэлсэн бүх үгээр дамжуулан хүн Сүнсний ажлыг, бие махбодтой болсон Бурханы хийдэг ажлыг, үүнээс ч илүүтэйгээр Түүний бүхий л зан чанарыг мэдэж авдаг. Бурханы зургаан мянган жилийн удирдлагын ажлын тухай мэдлэгийг чи бас үгээр дамжуулан олж авсан. Урьдын үзлийн талаарх мэдлэг болон тэдгээрийг орхисон амжилтад бас л үгээр дамжин хүрээгүй гэж үү? Өмнөх үе шатанд Есүс тэмдэг, гайхамшиг үзүүлсэн боловч энэ үе шатанд тэмдэг, гайхамшиг байхгүй. Бурхан яагаад тэмдэг, гайхамшиг илчилдэггүй тухай ойлголтод ч чи бас үгээр дамжин хүрээгүй гэж үү? Тиймээс энэ үе шатанд хэлсэн үг өнгөрсөн үеийн элч нар болон эш үзүүлэгчдийн хийсэн ажлаас даван гардаг. Эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлүүд ч ийм үр дүнд хүрч чадаагүй. Эш үзүүлэгчид зөвхөн зөгнөл хэлсэн ба тухайн үед Бурханы хийхийг хүсэж байсан ажлыг биш, харин ирээдүйд юу болох тухай л хэлсэн. Тэд хүний амьдралыг залж чиглүүлж, хүнд үнэнийг хайрлаж, эсвэл тэдэнд нууцыг илчлэхийн тулд, тэр ч бүү хэл амь хайрлахын тулд үг хэлээгүй. Энэ үе шатанд хэлсэн үгэнд зөгнөл болон үнэн байдаг боловч үндсэндээ эдгээр үг нь хүнд амь хайрлахын төлөө байдаг. Одоо үеийн үг нь эш үзүүлэгчдийн зөгнөлүүдтэй адилгүй. Энэ нь зөгнөл хэлэхийн төлөө биш, харин хүний амийн төлөөх, хүний амь зан чанарыг өөрчлөхийн төлөөх ажлын үе шат юм. Эхний үе шат нь Еховагийн ажил байсан: Түүний ажил нь газар дээр Бурханыг шүтэн мөргөх замыг хүнд зориулан бэлдэхийн төлөө байв. Энэ нь газар дээрх ажлын анхдагч газар нутгийг олох эхлэлийн ажил байсан юм. Тэр үед Ехова Амралтын өдрийг сахиж, эцэг эхээ хүндэтгэж, бие биетэйгээ эв найртай амьдрахад израильчуудыг сургасан. Учир нь, тухайн үеийн хүмүүс хүн гэж юу болохыг ойлгоогүй, мөн газар дээр яаж амьдрахыг ч ойлгоогүй. Ажлын эхний үе шатанд Тэрээр хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлэх шаардлагатай байсан юм. Еховагийн тэдэнд ярьсан бүхэн нь хүн төрөлхтний урьд нь мэддэггүй, эсвэл эзэмшдэггүй байсан зүйл байлаа. Тэр үед Бурхан олон эш үзүүлэгчийг зөгнөл хэлүүлэхээр өргөсөн ба тэд бүгд Еховагийн удирдамж дор ийнхүү хийсэн юм. Энэ нь зүгээр л Бурханы ажлын нэг хэсэг байв.

Эхний үе шатанд Бурхан махбод болоогүй, иймээс Тэр эш үзүүлэгчдээр дамжуулан бүх овог болон үндэстэнд зааварчилсан. Өөрийнхөө цаг үед ажиллаж байхдаа Есүс одоогийнх шиг их яриагүй. Эцсийн өдрүүд дэх үгийн ажлын энэ үе шатыг өмнө нь ямар ч эрин үед хийж байгаагүй юм. Хэдийгээр Исаиа, Даниел, Иохан нар олон зөгнөл хэлсэн боловч тэдний зөгнөлүүд одоо хэлж байгаа үгээс шал өөр байв. Тэдний хэлсэн зүйл ердөө зөгнөл байсан боловч одоо хэлдэг үг тийм биш. Хэрвээ Би одоо ярьдаг бүхнээ зөгнөл болгон хувиргавал та нар ойлгож чадах уу? Миний хэлсэн зүйл Намайг явсны дараах хэрэг явдлын тухай байсан гэж үзвэл та нар яаж ойлгож чадах юм бэ? Есүсийн цаг үед, эсвэл Хуулийн эрин үед үгийн ажил хэзээ ч хийгдээгүй. Магадгүй зарим нь: “Ехова ч бас ажиллаж байх үедээ үг хэлээгүй гэж үү? Өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөн зайлуулж, тэмдэг, гайхамшиг үзүүлэхээс гадна ажиллаж байхдаа Есүс ч бас үг хэлээгүй гэж үү?” хэмээн хэлэх байх. Хэлсэн зүйлсийн хооронд ялгаа байдаг. Еховагийн айлдсан үгийн мөн чанар юу байсан бэ? Тэр ердөө газар дээр амьдрахад нь хүмүүсийг залж чиглүүлж байсан ба амийн сүнслэг хэрэг явдлыг хөндөөгүй. Еховаг ярих үед энэ нь бүх газар нутгийн хүмүүст зааварчлахын төлөө байсан гэж яагаад хэлдэг вэ? “Зааварчлах” гэдэг үг нь тодорхой хэлж, шууд тушаах гэсэн үг. Тэрээр хүнийг амиар хангаагүй; харин, төдийлөн их сургаалт зүйрлэлгүйгээр, хүнийг зүгээр л гараас нь хөтөлж, Түүнийг яаж хүндэтгэхийг хүнд заасан. Еховагийн Израильд хийсэн ажил нь хүнтэй харьцаж, хүнийг сахилгажуулж, эсвэл хүнд шүүлт, гэсгээлт оноохын төлөө байгаагүй, харин хүнийг залж чиглүүлэхийн төлөө байсан юм. Цөлөөс манна цуглуул гэж Өөрийнх нь ардуудад хэлэхийг Ехова Мосед тушаасан. Өглөө бүр нар мандахаас өмнө тэд тухайн өдөр идэхэд нь л хангалттай хэмжээний манна түүдэг байлаа. Муудчихдаг байсан болохоор маннаг дараагийн өдөр болтол нь хадгалж болдоггүй байжээ. Тэр хүмүүст сургамжлаагүй, уг чанарыг нь ч илчлээгүй, мөн тэдний санаа бодлыг ч ил болгоогүй. Тэрээр хүмүүсийг өөрчлөөгүй, харин ч амьдралыг нь залж чиглүүлсэн юм. Тухайн үеийн хүмүүс яг л хүүхдүүд шиг, юу ч ойлгодоггүй байсан бөгөөд үндсэн хэдэн механик хөдөлгөөн л хийж чаддаг байсан тул Ехова олон түмнийг залж чиглүүлэхийн тулд л хууль гаргасан юм.

Үнэн сэтгэлээсээ эрж хайдаг бүх хүнийг өнөөдөр хийгдэж буй ажлын талаар мэдлэгтэй болгож, бүрмөсөн үнэмшүүлэхийн тулд сайн мэдээ түгээе гэвэл чи үе шат бүрд хийгдсэн ажлын дотоод түүх, мөн чанар, ач холбогдлыг тодорхой ойлгодог байх ёстой. Нөхөрлөлийг чинь сонсоод хүмүүс Еховагийн ажлыг болон Есүсийн ажлыг, тэр тусмаа өнөөдрийн Бурханы ажлыг, мөн ажлын гурван үе шатны холбоо болон ялгааг ойлгож болохуйц байлга. Сонсож дуусаад хүмүүс, гурван үе шат нь нэг нэгэндээ саад болдоггүй, харин бүгд нэг Сүнсний ажил, мөн хэдийгээр Тэд өөр өөр эрин үед ажиллаж, гүйцэтгэдэг ажлынх нь агуулга өөр, хэлдэг үг нь ч бас өөр байдаг боловч ажилладаг зарчим нь нэгэн ижил гэдгийг харахуйц байлга. Эдгээр зүйл бол Бурханыг дагадаг бүх хүний ойлгох ёстой хамгийн агуу үзэгдэл билээ.

ХОЁР УДАА БИЕ МАХБОДТОЙ БОЛОХ НЬ БИЕ МАХБОДТОЙ БОЛОХЫН АЧ ХОЛБОГДЛЫГ ГҮЙЦЭЭДЭГ

Бурханы хийсэн ажлын үе шат болгон өөрийн гэсэн бодит ач холбогдолтой. Тухайн үед Есүс ирэхдээ эрэгтэй хэлбэрээр ирсэн бол Бурхан энэ удаад эмэгтэй хэлбэрээр ирсэн. Үүнээс чи, Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн нь Өөрийнх нь ажилд Түүнд хүйсийн ялгаа байдаггүй. Түүний Сүнс ирэхдээ Өөрийн хүссэн ямар ч махбодыг сонгон авч болох бөгөөд тэрхүү махбод Түүнийг төлөөлж чадна; эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, Түүний махбод болсон бие мөн л бол Бурханыг төлөөлж чадна. Хэрвээ Есүс ирэхдээ эмэгтэй хүн болж гарч ирсэн бол, өөрөөр хэлбэл, Ариун Сүнснээс хүү биш, харин охин олдсон бол ажлын тэрхүү үе шат мөн л адилхан гүйцэлдэх байв. Хэрвээ тийм байсан бол ажлын одоогийн үе шатыг эрэгтэй хүн гүйцэлдүүлэх байсан, тэгсэн ч ажил мөн л адилхан хийгдэж дуусах байв. Үе шат бүрд хийгдсэн ажил өөрийн гэсэн ач холбогдолтой; ажлын аль ч үе шат давтагддаггүй, нөгөөтэйгөө ч зөрчилддөггүй. Тухайн үед, Есүс Өөрийн ажлыг хийж байхдаа цорын ганц Хүү гэж нэрлэгдэж байсан бөгөөд “Хүү” гэдэг нь эрэгтэй хүйс гэсэн утгыг агуулдаг. Тэгвэл одоогийн энэ үе шатанд яагаад цорын ганц Хүү гэж дурддаггүй вэ? Яагаад гэвэл, ажил нь Есүсийнхээс өөр хүйстэй байхыг шаардсан юм. Бурханы хувьд хүйсийн ялгаа ер байхгүй. Тэр Өөрийнхөө ажлыг хүссэнээрээ хийдэг ба ажлаа хийхдээ ямар ч хязгаарлалтад баригддаггүй, харин маш чөлөөтэй байдаг. Гэхдээ ажлын үе шат болгон өөрийн гэсэн бодит ач холбогдолтой. Бурхан хоёр удаа махбод болсон бөгөөд эцсийн өдрүүдийн үеэр бие махбодтой болдог нь сүүлчийнх гэдэг нь илэрхий юм. Тэрээр Өөрийн бүх үйл хэргийг мэдэгдэхийн тулд ирсэн. Хэрвээ энэ үе шатанд хүнд харуулах ажлаа биечлэн хийхийн тулд Тэр махбод болоогүй бол, Бурхан эмэгтэй биш, зөвхөн эрэгтэй гэсэн үзэлтэй хүн үүрд зууралдах байлаа. Үүнээс өмнө, Бурхан зөвхөн эрэгтэй байж болох бөгөөд эмэгтэй хүнийг Бурхан гэж нэрлэж болохгүй гэж бүх хүн итгэдэг байв, учир нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү эрх мэдэлтэй гэж бүгд үздэг байсан юм. Ямар ч эмэгтэй хүн эрх мэдлийг авч чадахгүй, зөвхөн эрэгтэй хүн л чадна гэж тэд итгэдэг байлаа. Тэр ч бүү хэл тэд, эрэгтэй хүн нь эмэгтэй хүний тэргүүн бөгөөд эмэгтэй хүн эрэгтэй хүнд дуулгавартай байх ёстой, эрэгтэй хүнээс илүү байж болохгүй гэж ч хэлдэг байв. Урьд нь, эрэгтэй хүн эмэгтэй хүний тэргүүн байсан гэж хэлэх үед энэ нь могойд мэхлэгдсэн Адам, Евад чиглэсэн болохоос бус, анх Еховагийн бүтээсэн эрэгтэй, эмэгтэй хүн рүү чиглээгүй юм. Мэдээж эмэгтэй хүн нөхөртөө дуулгавартай байж, түүнийг хайрлах ёстой, нөхөр нь гэр бүлээ тэжээж, тулж түшиж сурах ёстой. Энэ нь Еховагийн тогтоосон хууль, зарлиг бөгөөд хүн төрөлхтөн газар дээрх амьдралдаа үүнийг дагаж мөрдөх ёстой. Ехова эмэгтэй хүнд, “Эр нөхрөө чи эрмэлзэнэ, нөхөр чинь чамайг захирах болно” гэж хэлсэн. Хүн төрөлхтөн (өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүн хоёулаа) Еховагийн ноёрхол дор

хэвийн амьдралаар амьдарч, хүн төрөлхтний амьдрал зохион байгуулалттай, зөв зохистой дэг журмаа алдахгүй байгаасай гэсэндээ Тэр ингэж хэлсэн юм. Тиймээс Ехова эрэгтэй, эмэгтэй хүн хэрхэн үйлдэх ёстой талаар зөв зохистой дүрэм журам гаргасан, гэхдээ энэ нь газар дээр амьдарч байгаа бүх бүтээгдсэн зүйлд хамаатай байсан бөгөөд Бурханы махбод болсон биед ямар ч хамаагүй байлаа. Бурхан яаж Өөрийн бүтээсэн зүйлстэй адил байж болох юм бэ? Түүний үг Өөрийнх нь бүтээл болох хүн төрөлхтөн рүү л чиглэж байсан; хүн төрөлхтнийг хэвийн амьдралаар амьдруулахын тулд Тэр эрэгтэй, эмэгтэй хүнд зориулж дүрэм журам тогтоосон билээ. Анх Ехова хүн төрөлхтнийг бүтээхдээ хоёр төрлийн хүнийг буюу эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн; иймээс Түүний махбод болсон бие ч бас эрэгтэй, эмэгтэй болж хуваагддаг. Тэр Адам, Ева хоёрт хэлсэн үгэндээ үндэслэн Өөрийн ажлыг шийдээгүй. Тэр хоёр удаа махбод болсон нь бүхэлдээ, хүн төрөлхтнийг анх бүтээх үеийн Түүний бодлын дагуу тодорхойлогдсон, өөрөөр хэлбэл, ялзруулагдахаас өмнөх эрэгтэй, эмэгтэй хүнд үндэслэн Тэрээр хоёр удаа бие махбодтой болох ажлаа гүйцэтгэсэн юм. Хэрэв хүмүүс могойд мэхлэгдсэн Адам, Ева хоёрт Еховагийн хэлсэн үгийг аваад бие махбодтой болсон Бурханы ажилд хэрэглэсэн бол Есүс ч бас эхнэрээ хайрлах учиртай байсан бус уу? Тэгвэл Бурхан бас Бурхан хэвээр байх байсан уу? Хэрвээ тийм байсан бол Тэр Өөрийн ажлыг гүйцэлдүүлж мөн л чадах байсан уу? Хэрвээ Бурханы махбод болсон бие эмэгтэй байх нь буруу юм бол Бурхан эмэгтэй хүнийг бүтээсэн нь мөн асар том алдаа болохгүй гэж үү? Бурхан эмэгтэй хүн болж бие махбодтой болох нь буруу гэж хүмүүс итгэсээр байгаа бол гэрлээгүй, тийм ч болохоор Өөрийн эхнэрийг хайрлаж чадаагүй Есүс одоогийн бие махбодтой болсон Бурхантай адил ихээхэн алдаатай байх бус уу? Өнөө үеийн бие махбодтой болсон Бурханы үнэнийг хэмжихдээ чи Евад хэлсэн Еховагийн үгийг ашигладаг бол Нигүүлслийн эрин үед бие махбодтой болсон Эзэн Есүсийг үнэлэхдээ Адамд хэлсэн Еховагийн үгийг ашиглах ёстой. Энэ хоёр адилхан биш гэж үү? Чи могойд мэхлэгдээгүй эрэгтэйгээр Эзэн Есүсийг хэмждэг бол өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы үнэнийг могойд мэхлэгдсэн эмэгтэйгээр хэмжиж болохгүй. Энэ нь шударга бус! Бурханыг ингэж хэмжиж байгаа нь чамд саруул ухаан дутаж байгааг нотолдог. Ехова хоёр удаа махбод болох үед Түүний махбодын хүйс нь могойд мэхлэгдээгүй эрэгтэй, эмэгтэй хүнтэй хамаатай байсан; могойд мэхлэгдээгүй эрэгтэй, эмэгтэй хүний дагуу Тэр хоёр удаа махбод болсон юм. Есүсийн эрэгтэй чанар нь могойд мэхлэгдсэн Адамтай адил байсан гэж бүү бод. Тэр хоёр хоорондоо огт хамаагүй бөгөөд тэд бол өөр өөр шинж чанартай хоёр эрэгтэй юм. Есүсийн эрэгтэй чанар нь Тэрээр бүх эрэгтэй хүний бус, бүх эмэгтэй хүний тэргүүн гэдгийг баталж байгаа хэрэг биш биз дээ? Тэр бүх Иудейн (эрэгтэй болоод эмэгтэй аль алийг нь багтаагаад) Хаан биш гэж үү? Тэр бол Бурхан Өөрөө бөгөөд зөвхөн эмэгтэй хүний тэргүүн биш, бас эрэгтэй хүний ч тэргүүн юм. Тэрээр бүх бүтээлийн Эзэн бөгөөд бүх бүтээлийн тэргүүн билээ. Есүсийн эрэгтэй чанар нь эмэгтэй хүний тэргүүн

байхын бэлгэ тэмдэг гэж чи яаж тодорхойлж чадаж байна вэ? Энэ нь доромжлол биш гэж үү? Есүс бол ялзруулагдаагүй эрэгтэй. Тэр бол Бурхан; Тэр бол Христ; Тэр бол Эзэн. Тэр яаж ялзарсан Адамтай адилхан эрэгтэй байх юм бэ? Есүс бол хамгийн ариун Бурханы Сүнсний өмссөн махбод юм. Тэр бол Адамын эрэгтэй чанарыг эзэмшдэг Бурхан гэж чи яаж хэлж чадаж байна вэ? Тэр тохиолдолд Бурханы бүх ажил буруу байх байсан биш гэж үү? Ехова могойд мэхлэгдсэн Адамын эрэгтэй чанарыг Есүсийн дотор нэгтгэх байсан уу? Өнөө үеийн бие махбодтой Бурхан нь хүйсээрээ Есүсээс ялгаатай боловч уг чанарааараа адилхан бие махбодтой болсон Бурханы ажлын өөр нэг тохиолдол биш гэж үү? Могойд эхлээд мэхлэгдсэн хүн нь эмэгтэй байсан учраас бие махбодтой болсон Бурхан эмэгтэй байж болохгүй гэж чи одоо ч хэлж зүрхлэх үү? Эмэгтэй хүн бол хамгийн бузар бөгөөд хүн төрөлхтний ялзралын эх сурвалж тул Бурхан эмэгтэй хүнтэй адил махбод болж болохгүй гэж мөн л хэлж зүрхлэх үү? Чи, “эмэгтэй хүн үргэлж эрэгтэй хүнд дуулгавартай байх ёстой, хэзээ ч Бурханыг илэрхийлж, эсвэл шууд төлөөлж чадахгүй” гэж хэлж зүрхэлсээр л байна уу? Чи өмнө нь ойлгоогүй байсан боловч одоо ч гэсэн Бурханы ажлыг, ялангуяа Бурханы махбод болсон биеийг доромжилсоор байж чадах уу? Хэрвээ чи үүнийг тов тодорхой ойлгож чадахгүй бол хэл амаа анхаарч байсан нь дээр, тэнэглэл болон мэдлэггүй байдал чинь илчлэгдэж, муу муухай чинь илрэх вий. Чи бүхнийг ойлгодог гэж бүү бод. Миний удирдлагын төлөвлөгөөний мянганы нэг хэсгийг ойлгоход ч харсан, туулсан бүхэн чинь хангалттай биш гэдгийг Би чамд хэлж байна. Тэгвэл яагаад чи ийм ихэрхүү авирладаг юм бэ? Чиний өчүүхэн жаахан авьяас, туйлын бага мэдлэгийг Есүс Өөрийнхөө ажлын нэг секундэд ч ашиглахад хангалтгүй юм! Чи үнэндээ хэр их туршлагатай вэ? Бүх насаараа харсан, сонссон, төсөөлсөн бүхэн чинь Миний агшин зуур хийдэг ажлаас ч бага! Чи өөнтөглөхгүй байсан нь дээр. Чи хүссэнээрээ биеэ тоож болно, гэхдээ чи бол шоргоолжны хэмжээнд ч хүрэхгүй бүтээлээс цаашгүй! Гэдсэн дотроо агуулдаг бүхэн чинь шоргоолжны гэдсэнд байдгаас ч бага! Бага зэрэг туршлага, зэрэг зиндаа олж авсан учраас энэ нь чамд цадиггүйгээр дохиж зангаж, сайрхах эрх олгодог гэж бүү бод. Чиний туршлага болон зэрэг зиндаа Миний айлдсан үгийн үр дүн биш гэж үү? Чи тэдгээрийг шаргуу ажил, хөдөлмөрийн чинь үр дүнд ирсэн гэж итгэж байна уу? Өнөөдөр чи махбод болсныг минь харж байна, гагцхүү үүнээс л болж чиний дотор хангалттай баялаг ойлголт, хязгааргүй их үзэл байдаг. Хэрвээ Би бие махбодтой болоогүй бол чи ер бусын авьяастай байсан ч гэсэн ийм их уран сэтгэмжтэй болохгүй байх байсан; эдгээрээс чиний үзэл гарч ирдэггүй гэж үү? Хэрвээ Есүс анх махбод болоогүй байсан бол чи бие махбодтой болох талаар мэдэх байсан гэж үү? Эхний удаа бие махбодтой болсон нь чамд мэдлэг өгсөн болохоор хоёр дахь удаа бие махбодтой болсныг нь шүүх гэж оролдох эрээ цээргүй зан чамд байгаа бус уу? Дуулгавартай дагагч байхын оронд чи яагаад үүнийг судалж шинжлэх ёстой юм бэ? Чамайг энэ урсгалд орж, бие махбодтой болсон Бурханы өмнө ирэх үед үүнийг судлахыг чинь Тэр чамд

зөвшөөрөх үү? Чи гэр бүлийнхээ түүхийг судалж болно, гэтэл Бурханы “гэр бүлийн түүхийг” судлахаар оролдвол өнөөдрийн Бурхан ийм судалгаа хийхийг чинь зөвшөөрөх үү? Чи сохор бус уу? Чи жигшил зэвүүцэл төрүүлдэггүй гэж үү?

Хэрвээ эцсийн өдрүүдийн энэхүү үе шатан дахь ажлыг нэмэхгүйгээр зөвхөн Есүсийн ажил хийгдсэн бол, Есүс ганцаараа л Бурханы цорын ганц Хүү, өөрөөр хэлбэл, Бурханд цорын ганц хүү байдаг бөгөөд дараа нь өөр нэрээр ирсэн хэн боловч Бурхан Өөрөө байх нь бүү хэл, Бурханы цорын ганц Хүү ч биш гэсэн үзлийг хүн үүрд хадгалах байсан юм. Нүглийн тахил болон үйлчилж, эсвэл Бурханы өмнөөс эрх мэдлийг гартаа авч, бүх хүн төрөлхтнийг золин авардаг хүн л Бурханы цорын ганц Хүү юм гэсэн үзэл хүнд байдаг. Ирдэг Нэгэн нь эрэгтэй байх л юм бол Түүнийг Бурханы цорын ганц Хүү болон Бурханы төлөөлөгч гэж үзэж болно хэмээн итгэдэг зарим хүн байдаг бөгөөд Есүс бол Еховагийн Хүү, Түүний цорын ганц Хүү гэж хэлдэг ч хүмүүс бий. Энэ нь хүний хэтрүүлэгтэй үзэл биш гэж үү? Хэрвээ ажлын энэ үе шат нь эцсийн эрин үед хийгдээгүй байсан бол Бурханы тухайд бүх хүн төрөлхтөн харанхуйн сүүдэрт хучигдах байв. Хэрвээ ийм байсан бол эрэгтэй хүн өөрийгөө эмэгтэй хүнээс илүү дээр гэж бодох байсан ба эмэгтэйчүүд хэзээ ч толгой өргөн явж чадахгүй байх байсан, тэгвэл ганц ч эмэгтэй хүн аврагдаж чадахгүй байх байлаа. Бурхан бол эрэгтэй, түүнээс гадна Тэр үргэлж эмэгтэй хүнийг үзэн яддаг бөгөөд түүнд аврал хайрлахгүй байсан гэдэгт хүмүүс үргэлж итгэдэг. Хэрвээ ийм байсан бол Еховагийн бүтээсэн, бас ялзарсан бүх эмэгтэй хүн хэзээ ч аврагдах боломжгүй байх байсан бус уу? Тэгвэл Ехова эмэгтэй хүнийг бүтээсэн нь, өөрөөр хэлбэл, Еваг бүтээсэн нь утгагүй байх байсан бус уу? Эмэгтэй хүн мөнхөд мөхөх байсан бус уу? Ийм шалтгааны улмаас, эцсийн өдрүүд дэх ажлын үе шат нь зөвхөн эмэгтэй хүнийг биш, харин бүх хүн төрөлхтнийг аврахын тулд хийгддэг. Бурхан эмэгтэй хүний дүрээр бие махбодтой болбол, тэр нь гагцхүү эмэгтэй хүнийг аврахын төлөө байна гэж хэн нэгэн бодох юм бол тэр хүн үнэхээр тэнэг юм!

Өнөөдрийн ажил Нигүүлслийн эрин үеийн ажлыг урагшлуулсан; өөрөөр хэлбэл, бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх ажил урагшилсан. Хэдийгээр Нигүүлслийн эрин үе дууссан ч Бурханы ажилд ахиц гарлаа. Ажлын энэ үе шат нь Нигүүлслийн эрин үе болон Хуулийн эрин үед үндэслэн хийгддэг гэж Би яагаад ахин дахин хэлдэг вэ? Яагаад гэвэл, өнөөдрийн ажил бол Нигүүлслийн эрин үед хийгдсэн ажлын үргэлжлэл бөгөөд Хуулийн эрин үед хийгдсэн зүйлийн ахиц дэвшил юм. Гурван үе шат нь өөр хоорондоо нягт харилцан холбогдсон ба гинжин холбоос нэг бүр нь дараагийнхтайгаа нягт холбогдсон байдаг. Ажлын энэхүү үе шат нь Есүсийн хийсэн дээр тулгуурлан хийгддэг гэж Би бас яагаад хэлдэг вэ? Энэ үе шат Есүсийн хийсэн ажилд тулгуурлан хийгдээгүй гэж үзвэл энэ үе шатанд өөр цовдлол явагдах хэрэгтэй болох байсан бөгөөд өмнөх үе шатны золин аврах ажлыг дахиад эхнээс нь хийх хэрэгтэй болох байв. Энэ нь утгагүй байх байлаа. Иймээс ажил бүрэн дууссан юм биш, харин эрин үе урагшилсан бөгөөд ажлын түвшин өмнөхөөсөө бүр ч илүү өндөрт өргөгдсөн юм. Ажлын энэхүү үе шат Хуулийн эрин

үеийн суурин дээр, Есүсийн ажлын суурин дээр хийгдсэн гэж хэлж болно. Бурханы ажил шат шатаар хийгдсэн бөгөөд энэ үе шат нь шинэ эхлэл биш юм. Ажлын гурван үе шатны хослолыг л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гэж үзэж болно. Энэ үе шатны ажил нь Нигүүлслийн эрин үеийн ажлын суурин дээр хийгддэг. Хэрвээ ажлын энэ хоёр үе шат хоорондоо хамааралгүй байсан бол яагаад энэ үе шатанд цовдлол давтагддаггүй вэ? Яагаад Би хүний нүглийг үүрэхийн оронд хүнийг шууд шүүж, гэсгээдэг вэ? Хэрвээ хүнийг шүүж, гэсгээх Миний ажил цовдлолын дараа болоогүй, одоо ирж байгаа минь Ариун Сүнснээс олдож төрөөгүй бол Би хүнийг шүүж, гэсгээх эрхгүй байх байлаа. Би Есүстэй нэг учраас л хүнийг шууд гэсгээж, шүүж эхэлдэг. Энэ үе шатан дахь ажил бүхэлдээ өмнөх үе шатны ажил дээр суурилсан. Тийм учраас, ийм ажил л хүнийг алхам алхмаар авралд хүргэж чадна. Есүс Бид хоёр нэг Сүнснээс ирсэн. Бидний махбод ямар ч хамаагүй хэдий ч Бидний Сүнс нэг юм; Бидний хийдэг зүйлийн агуулга болон Бидний хариуцдаг ажил адилхан биш хэдий ч мөн чанартаа Бид адилхан; Бидний махбод өөр өөр дүр төрхтэй болсон нь эрин үеийн өөрчлөлт болон ажлын маань өөр өөр шаардлагаас үүдэлтэй; Бидний үйлчлэл адилгүй, иймээс Бидний авчирдаг ажил болон хүнд илчилдэг Бидний зан чанар бас өөр. Тийм учраас өнөөдөр хүний харж, ойлгодог зүйл өнгөрсөн үеийнхтэй адилгүй байдаг нь эрин үеийн өөрчлөлтөөс үүддэг. Хэдийгээр Тэдний махбодын хүйс, дүр төрх өөр, мөн Тэд нэгэн цаг үед байтугай, нэг гэр бүлд төрөөгүй боловч Тэдний Сүнс нэг билээ. Тэдний махбод ямарваа төрлийн мах цусны барилдлагагүй ч Тэд бол хоёр өөр цаг хугацаанд бие махбодтой болсон Бурхан гэдгийг үгүйсгэж болохгүй. Тэд бол Бурханы махбод болсон бие гэдэг нь няцаашгүй үнэн. Гэхдээ, Тэд нэг удам сударгүй, эсвэл нэг хэлээр ярьдаггүй (нэг нь иудейчүүдийн хэлээр ярьдаг эрэгтэй хүн байсан, нөгөө нь Хятад хэлээр л ярьдаг эмэгтэй хүн). Эдгээр шалтгааны улмаас Өөрсдийн хийх учиртай ажлыг хийхийн тулд Тэд өөр өөр улс оронд, бас өөр өөр цаг үед амьдарсан. Тэд адилхан мөн чанартай Сүнс хэдий ч Тэдний махбодын гадаад бүрхүүлийн хооронд туйлын адил төстэй зүйл огтхон ч байхгүй. Тэд адилхан хүн чанартай ч Тэдний махбодын гадаад төрх болон төрөлтийн нөхцөл байдал адилгүй. Эдгээр зүйл Тэдний тус тусын ажил юм уу Тэдний талаарх хүний мэдлэгт ямар ч нөлөөгүй, учир нь эцсийн дүндээ Тэд бол адилхан Сүнс бөгөөд хэн ч Тэднийг салгаж чадахгүй. Хэдий Тэд цусан холбоогүй боловч Тэдний бүхий л оршихуйг Өөрсдийнх нь Сүнс захирдаг, энэ нь Тэдэнд өөр өөр цаг үед, өөр өөр ажил оноодог ба Тэдний махбод өөр өөр удам судартай. Еховагийн Сүнс нь Есүсийн Сүнсний эцэг биш, мөн Есүсийн Сүнс нь Еховагийн Сүнсний хүү биш: Тэд бол нэг Сүнс юм. Үүний адилаар өнөөдрийн бие махбодтой болсон Бурхан, Есүс хоёр цусан хамааралгүй ч Тэд бол нэг; яагаад гэвэл, Тэдний Сүнс нэг юм. Бурхан өршөөл, хайр энэрлийн ажлыг, түүнчлэн хүнийг зөв шударгаар шүүж, гэсгээх ажлыг, мөн хүнд хараал учруулах ажлыг хийж чадна; эцэст нь Тэрээр дэлхийг устгаж, хорон муу хүмүүсийг шийтгэх ажлыг хийж чадна. Тэр Өөрөө энэ бүхнийг

хийдэггүй гэж үү? Энэ нь Бурханы бүхнийг чадагч байдал биш гэж үү? Тэрээр хүний төлөө хууль тогтоож, түүнд зориулан тушаал гаргахын аль алиныг хийж чадсан ба түүнчлэн тухайн үеийн израильчуудыг газар дээр амьдрахад нь залж чиглүүлж, сүм болон тахилын ширээ барихад нь тэдэнд зааварчилж, бүх израильчуудыг Өөрийнхөө эрх мэдэл дор байлгаж чадсан. Өөрийнхөө эрх мэдлээс үүдэн Тэр Израилийн ард түмэнтэй хамт газар дээр хоёр мянган жилийн турш амьдарсан юм. Израильчууд Түүний эсрэг тэрсэлж зүрхлээгүй; бүгд Еховаг хүндэтгэж, Түүний тушаалуудыг мөрджээ. Энэ нь, Түүний эрх мэдэл, бүхнийг чадагч байдалд түшиглэн хийгдсэн ажил байв. Дараа нь Нигүүлслийн эрин үед Есүс унасан бүх хүн төрөлхтнийг (зөвхөн израильчуудыг ч биш) золин аврахаар ирсэн юм. Тэрээр хүнд өршөөл, хайр энэрлийг харуулсан. Нигүүлслийн эрин үед хүний харсан Есүс хайр энэрлээр бялхаж, хүнийг үргэлж хайрладаг байсан, учир нь Тэр хүмүүсийг нүглээс аврахаар ирсэн юм. Өөрийнх нь цовдлол хүн төрөлхтнийг нүглээс бүрэн золин аврах хүртэл Тэр хүмүүсийн нүглийг уучилж чаддаг байлаа. Тэр үед, Бурхан хүний өмнө өршөөл, хайр энэрэлтэйгээр гарч ирсэн; өөрөөр хэлбэл, Тэр хүний төлөө нүглийн тахил болж, хүний нүглийн төлөө цовдлогдож, нүглийг нь үүрд уучилсан билээ. Тэрээр өршөөнгүй, энэрэнгүй, тэвчээртэй агаад элэгсэг байсан юм. Нигүүлслийн эрин үед Есүсийг дагасан хүмүүс ч бас бүх зүйл дээр тэвчээртэй, энэрэнгүй байхаар хичээж байсан. Тэд урт удаан хугацаанд зовсон бөгөөд зодуулж, хараалгаж, эсвэл чулуугаар шидүүлж байсан ч хэзээ ч эсэргүүцээгүй. Гэхдээ сүүлийн үе шатанд дахин тийм байж болохгүй. Есүс, Ехова хоёрын Сүнс нэг байсан хэдий ч Тэдний ажил бүхэлдээ адилхан байгаагүй. Еховагийн ажил эрин үеийг төгсгөөгүй, харин эрин үеийг удирдаж, газар дээрх хүн төрөлхтний амьдралыг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийн ажил нь Харь үндэстнүүд дэх гүнзгий ялзруулагдсан хүмүүсийг байлдан дагуулж, Хятад дахь Бурханы сонгосон хүмүүсийг төдийгүй, бүхий л орчлон ертөнц, бүх хүн төрөлхтнийг удирдахын төлөө байдаг. Энэ ажил одоо зөвхөн Хятадад хийгдэж байна гэж чамд харагдаж болох боловч үнэндээ энэ нь аль хэдийн хилийн чанадад түгэж эхэлсэн. Хятадын гаднах хүмүүс яагаад үнэн замыг ахин дахин эрж хайдаг юм бэ? Яагаад гэвэл Сүнс аль хэдийн ажиллаж эхэлсэн ба өнөөдөр хэлсэн үг орчлон ертөнц дахины хүмүүст чиглэдэг. Үүний хамтаар ажлын тэн хагас аль хэдийн хийгдсэн. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөг хүртэл Бурханы Сүнс ийм агуу ажлыг хийж эхэлсэн бөгөөд түүнчлэн өөр өөр эрин үед, өөр өөр улс үндэстэнд ялгаатай ажил хийсэн юм. Эрин үе бүрийн хүмүүс Түүний хийдэг өөр өөр ажлаар аяндаа илчлэгддэг өөр өөр зан чанарыг нь хардаг. Тэр бол өршөөл, хайр энэрлээр дүүрэн Бурхан; Тэр бол хүний төлөөх нүглийн тахил бөгөөд хүний хоньчин; гэхдээ Тэр бас хүний шүүлт, гэсгээлт болон хараал юм. Тэрээр хүнийг газар дээр амьдрахад нь хоёр мянган жилийн турш удирдаж, бас ялзарсан хүн төрөлхтнийг нүглээс золин аварч чадсан. Өнөөдөр Тэр бас Өөрийг нь мэддэггүй хүн төрөлхтнийг байлдан дагуулж, Өөрийнхөө эрх мэдэл дор байлгаж, бүгдийг нь Өөртөө бүрэн захирагдуулж чаддаг. Эцэст нь, Тэрээр

орчлон ертөнц дахины хүмүүсийн доторх бузар, зөв шударга бус бүгдийг шатаан, Тэр бол өршөөнгүй, энэрэнгүй Бурхан, мэргэн ухаан, гайхамшгийн Бурхан, мөн ариун Бурхан байгаад зогсохгүй, түүнчлэн хүнийг шүүдэг Бурхан юм гэдгийг хүмүүст харуулна. Хүн төрөлхтний дундах муу хүмүүст Тэр бол шатаалт, шүүлт, шийтгэл; төгс болгуулах хүмүүст Тэр бол гай зовлон, цэвэршүүлэлт, шалгалт, түүнчлэн тайтгарал, дэмжлэг, үгийн хангалт, харьцалт, засалт юм. Таягдан хаягдах хүмүүст бол Тэрээр шийтгэл, мөн залхаан цээрлүүлэлт билээ. Надад хэлээч, Бурхан төгс хүчит биш гэж үү? Тэр чиний төсөөлдөг шиг зөвхөн цовдлолыг биш, харин аливаа бүх ажлыг хийх чадвартай. Чи Бурханыг хэтэрхий доогуур бодож байна! Тэрээр цовдлолоор дамжуулан бүх хүн төрөлхтнийг золин аварч л чадна, тэгээд л тэр гэж чи итгэж байна уу? Үүний дараа чи амийн модны жимсийг идэж, амийн голоос уухын тулд тэнгэр өөд Түүнийг дагах уу?… Ийм энгийн байж болно гэж үү? Надад хэл дээ, чи юу хийж гүйцэлдүүлсэн юм бэ? Чамд Есүсийн амь байгаа юу? Чи үнэндээ Түүгээр золин авруулсан, гэхдээ цовдлол нь Есүсийн Өөрийнх нь ажил байсан. Хүний хувиар чи ямар үүрэг гүйцэтгэсэн бэ? Чамд гадаад талын сүсэг бишрэл л байдаг боловч Түүний замыг ойлгодоггүй. Ингэж чи Түүнийг харуулдаг юм уу? Хэрвээ чи Бурханы амийг олж аваагүй, эсвэл Түүний зөвт зан чанарыг бүхэлд нь хараагүй бол өөрийгөө амьтай нэгэн гэж хэлж болохгүй бөгөөд тэнгэрийн хаанчлалын хаалгаар ороход тэнцэхгүй.

Бурхан Сүнс байгаад зогсохгүй, бас махбод болж чаддаг. Түүнчлэн Тэр бол алдрын бие мөн. Хэдий та нар Есүсийг хараагүй боловч тухайн үеийн израильчууд буюу иудейчүүд Түүнийг нүдээрээ харсан. Тэр эхлээд махбодтой бие байсан, харин цовдлогдсоныхоо дараа алдрын бие болсон. Тэр бол бүхнийг хамрагч Сүнс бөгөөд газар бүрд ажиллаж чаддаг. Тэр Ехова, Есүс, эсвэл Мессиа байж чадна; эцэст нь Тэр бас Төгс Хүчит Бурхан болж чадна. Тэр бол зөвт байдал, шүүлт, гэсгээлт; Тэр бол хараал, уур хилэн; гэхдээ Тэр бас өршөөл, хайр энэрэл юм. Түүний хийсэн бүх ажил Түүнийг төлөөлөх чадвартай. Түүнийг ямархуу Бурхан гэж чи хэлэх вэ? Чи тайлбарлаж чадахгүй. Хэрвээ чи үнэхээр тайлбарлаж чадахгүй бол Бурханы талаар дүгнэлт гаргах ёсгүй. Нэг үе шатанд золин авралын ажил хийснээс нь болж Бурхан бол үүрд өршөөл, хайр энэрлийн Бурхан байна гэсэн дүгнэлт бүү гарга. Тэр зөвхөн өршөөнгүй, энэрэнгүй Бурхан байна гэдэгт чи итгэлтэй байж чадах уу? Хэрвээ Тэр ердөө өршөөнгүй, энэрэнгүй Бурхан юм бол яагаад эцсийн өдрүүдэд эрин үеийг төгсгөх вэ? Яагаад маш олон гамшгийг илгээх вэ? Хүмүүсийн үзэл, бодлын дагуу бол хүн төрөлхтний гишүүн нэг бүрийг аврахын тулд Бурхан бүр эцсээ хүртэл өршөөнгүй, энэрэнгүй байх ёстой. Гэтэл эцсийн өдрүүдэд, Бурханыг дайснаа гэж үздэг ёрын муу энэ хүн төрөлхтнийг устгахын тулд Тэр яагаад газар хөдлөлт, тахал, өлсгөлөн гэх мэтийн агуу гамшгийг буулгадаг юм бэ? Яагаад Тэр хүнийг эдгээр гамшгаас болж зовохыг зөвшөөрдөг вэ? Бурхан ямархуу болохыг та нарын дундаас хэн ч хэлж зүрхэлдэггүй, хэн ч тайлбарлаж чаддаггүй. Тэр бол үнэхээр Сүнс гэж чи хэлж зүрхлэх үү? Тэр бол Есүсийн махбодоос өөр хэн ч биш

гэж хэлж зүрхлэх үү? Мөн чи Түүнийг хүний төлөө үүрд цовдлогдох Бурхан гэж хэлж зүрхлэх үү?

ГУРВАЛ ОРШИН БАЙДАГ УУ?

Есүс махбод болсон тухай үнэн ил болсны дараа хүн тэнгэрт Эцэг байдгаар үл барам, мөн Хүү, бүр Сүнс ч байдаг. Тэнгэрт ийм Бурхан буюу Эцэг, Хүү, Ариун Сүнс гэх гурвал Бурхан байдаг гэдэг нь хүний уламжлалт үзэл юм. Бүх хүн төрөлхтөнд ийм үзэл байдаг: Бурхан бол нэг Бурхан, гэхдээ гурван хэсгээс бүрддэг ба уламжлалт үзэлд ноцтойгоор заншиж тогтсон зүйлс нь Эцэг, Хүү, Ариун Сүнс юм. Энэ гурван хэсгийг нийлүүлсэн нь л Бурхан бүхэлдээ юм. Ариун Эцэггүйгээр Бурхан бүрэн гүйцэд байж чадахгүй. Үүнтэй адилаар Хүү, эсвэл Ариун Сүнсгүйгээр Бурхан мөн л бүрэн гүйцэд байхгүй. Өөрсдийн үзэлд хүмүүс Эцгийг ганцааранг нь, мөн Хүүг ганцааранг нь Бурхан гэж үзэж болохгүй хэмээн итгэдэг. Зөвхөн Эцэг, Хүү, Ариун Сүнсийг хамтад нь Бурхан Өөрөө гэж үзэж болно. Одоо шашны бүх итгэгч, бүр та нарын дундах дагалдагч болгон энэ итгэлийг баримталдаг. Гэсэн ч та нар Бурханы Өөрийн хэрэг явдлын талаар үргэлж төөрөгдлийн манан дунд байдаг учраас энэхүү итгэл зөв эсэх талаар хэн ч тайлбарлаж чадахгүй. Хэдий эдгээр нь үзэл боловч та нар зөв, буруу эсэхийг нь мэддэггүй, учир нь шашны үзэл та нарт хэтэрхий ноцтойгоор халдварласан. Та нар шашны эдгээр уламжлалт үзлийг хэтэрхий гүн гүнзгий хүлээн зөвшөөрсөн ба энэхүү хор дотор чинь дэндүү гүн нэвчсэн. Тиймээс энэхүү асуудал дээр ч та нар энэ хортой нөлөөнд автсан, учир нь гурвал Бурхан ердөө оршин байдаггүй. Өөрөөр хэлбэл, Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвал ердөө оршин байдаггүй. Эдгээр нь бүгд хүний уламжлалт үзэл, хүний эндүү ташаа ойлголт билээ. Олон зууны туршид, хүний оюун санаан дахь үзлээс бий болсон, хүний зохиосон, урьд нь хэзээ ч хүнд үзэгдэж байгаагүй энэхүү Гурвалд хүн итгэсэн. Энэ олон жилийн туршид Гурвалын “жинхэнэ утгыг” тайлбарласан Библийн тайлбарлагчид олон байсан боловч гурвал Бурханыг гурван өөр нэгдмэл бодгаль хэмээсэн тийм тайлбар нь тодорхой бус, ойлгомжгүй байсан ба хүмүүс бүгд Бурханы “бүтцийн” талаар будилдаг. Ямар ч агуу хүн бүрэн гүйцэд тайлбар өгч огт чадаагүй; ихэнх тайлбар нь учир шалтгааны хувьд болон бичиг цаасан дээр шаардлага хангадаг боловч нэг ч хүн үүний утга учрыг тов тодорхой ойлгодоггүй. Яагаад гэвэл, хүний зүрх сэтгэлдээ хадгалдаг агуу Гурвал ердөө оршин байдаггүй. Учир нь хэн ч Бурханы жинхэнэ төрхийг харж байгаагүй, мөн Бурханы оршдог газарт ямар зүйл байдгийг шинжлэхийн тулд, “Бурханы гэр”-т яг хэдэн арван мянга, хэдэн зуун сая үе удам байгааг тодорхойлохын тулд, эсвэл Бурханы төрөлхийн бүтцийг яг хэдэн хэсэг бүрдүүлдгийг шалгахын тулд Бурханы оршин байгаа газарт зочлохоор дээш гарах хувьтай хүн нэг ч байгаагүй. Үндсэндээ юуг шинжлэх хэрэгтэй вэ гэвэл: Эцэг, Хүү, бас Ариун Сүнсний нас; бодгаль тус бүрийн харагдах

байдал; Тэд яг хэрхэн хуваагддаг болон хэрхэн нэг болдог явдал юм. Харамсалтай нь, энэ бүх жилүүдэд нэг ч хүн энэ хэрэг явдлын үнэнийг тодорхойлж чадаагүй. Гурвалын талаар анхаардаг, шашны тэр бүх үнэн сүсэгт, цогтой итгэгчдэд хэрэг явдлын үнэнийг тайлагнахын тулд хэн ч, хэзээ ч тэнгэр лүү зочлохоор дээш гарч, бүх хүн төрөлхтөнд зориулсан “эрэн сурвалжлах тайлантайгаар” буцаж ирээгүй учраас тэд бүгдээрээ зүгээр л таамагладаг. Мэдээж ийм үзлийг бий болгосных нь төлөө хүнийг буруутгаж болохгүй, тэгвэл яагаад Эцэг Ехова хүн төрөлхтнийг бүтээхдээ Хүү Есүсийг дагуулж яваагүй юм бэ? Эхэндээ бүгд Еховагийн нэрээр явсан бол энэ нь илүү дээр байх байсан юм. Хэрвээ буруутгах ёстой юм бол, бүтээлийн цаг үед Хүү болон Ариун Сүнсийг Өөрийнхөө өмнө дуудалгүй, харин ч Өөрийн ажлыг ганцаараа хийсэн Ехова Бурханы түр зуурын ташаарлыг л буруутга. Тэд бүгд нэгэн зэрэг ажилласан бол нэг болох байсан бус уу? Хэрвээ бүр эхнээсээ эцсээ хүртэл зөвхөн Ехова гэх нэр байж, Нигүүлслийн эрин үеийн Есүсийн нэр байгаагүй бол, эсвэл тухайн үед Бурхан Ехова гэж нэрлэгдсээр байсан бол хүн төрөлхтний үүсгэсэн энэхүү хуваагдлын зовлонгоос салах байсан бус уу? Мэдээж, энэ бүхний төлөө Еховаг буруутгаж болохгүй; хэрвээ буруутгах ёстой бол олон мянган жилийн турш Ехова, Есүс, тэр ч бүү хэл Ариун Сүнсний нэрээр Өөрийн ажлыг үргэлжлүүлэн хийж, Бурхан гэж яг юу вэ гэдгийг мэдэхээ больтол нь хүнийг будилуулж, төөрөлдүүлсэн Ариун Сүнсийг л буруутга. Хэрвээ Ариун Сүнс Өөрөө хэлбэр дүрс, дүр төрхгүйгээр, түүнчлэн Есүс гэх мэт нэргүйгээр ажиллаж, хүн Түүнд хүрч ч, харж ч чадахгүй, зөвхөн аянгын дууг сонсдог байсан бол ийм төрлийн ажил нь хүн төрөлхтөнд илүү их ач тустай байх байсан бус уу? Тэгвэл одоо юу хийж болох вэ? Хүний үзэл уул шиг өндөр, далай шиг өргөн уудам болж овоорсон ба өнөөгийн Бурхан цаашид тэдгээрийг тэвчиж чадахгүй, яахаа мэдэхгүй байх хэмжээнд очсон. Урьд нь Ехова, Есүс болон Тэдний дундах Ариун Сүнс байх үед хүн яаж учрыг нь олохоо аль хэдийн мэдэхээ больсон байсан ба одоо үүн дээр нэмээд мөн л Бурханы нэг хэсэг гэж хэлэгддэг Төгс Хүчит байгаа. Тэр хэн бэ гэдгийг болон Гурвалын аль бодгальтай Тэр холилдсон, эсвэл хэчнээн олон жилийн турш дотор нь нуугдсан гэдгийг хэн мэдэх билээ? Хүн яаж үүнийг тэвчиж чадах юм бэ? Насан туршдаа тайлбарлахад гурвал Бурхан дангаараа хангалттай байсан атал одоо “дөрвөн бодгаль дахь нэг Бурхан” байна. Үүнийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Чи тайлбарлаж чадах уу? Ах, эгч нар аа! Өнөөдрийг хүртэл та нар ийм Бурханд яаж итгэж байсан юм бэ? Би та нарыг биширч байна. Гурвал Бурханыг тэвчих нь аль хэдийн хангалттай байсан; гэтэл та нар дөрвөн бодгаль дахь энэ нэг Бурханд ийм тууштай итгэсээр байж яаж чадаж байна вэ? Та нараас явахыг шаардсан ч та нар татгалздаг. Үнэхээр санаанд багтамгүй! Та нар үнэхээр сүрхий юм! Хүн үнэндээ дөрвөн Бурханд ч гэсэн итгээд, үүнийгээ юман чинээ бодохгүй байж чадна; та нар үүнийг гайхамшиг гэж бодохгүй байна уу? Та нарыг хараад ийм агуу гайхамшиг үзүүлж чадна гэдгийг чинь хэн ч мэдэхгүй! Үнэндээ энэ орчлон ертөнцийн хаа ч гурвал Бурхан оршдоггүй гэдгийг Би та нарт хэлье. Бурханд Эцэг байхгүй, Хүү

байхгүй, тэр ч бүү хэл Эцэг, Хүү хоёр хамтдаа Ариун Сүнсийг хэрэгсэл болгон ашигладаг гэх ухагдахуун ч байхгүй. Энэ бүхэн нь энэ дэлхийн хамгийн гажууд онол бөгөөд огт оршдоггүй! Гэхдээ ийм гажууд онол ч гэсэн эх сурвалжтай байдаг бөгөөд огт үндэслэлгүй байдаггүй, учир нь та нарын оюун санаа тийм ч энгийн биш, мөн та нарын бодол үндэслэлгүй биш билээ. Харин ч тэдгээр нь нэлээд зохистой, ухаалаг, бүр ямар ч Сатан нэвтэршгүй байдаг. Харамсалтай нь эдгээр бодол бүгд гажууд онол бөгөөд зүгээр л оршин байдаггүй! Та нар жинхэнэ үнэнийг огтхон ч хараагүй; та нар бусдын итгэлийг овжноор олж, оюуны чадамжгүй буюу эрүүл ухаангүй хамгийн тэнэг хүмүүсийг ноёлж, тэднийг агуу, алдартай “мэргэжилтний сургаал”-даа итгүүлэхийн тулд зүгээр л таамаглал, төсөөлөл бий болгож, үүнийгээ янз бүрийн түүх болгон зохиодог. Энэ нь үнэн үү? Энэ нь хүний хүлээн авах ёстой амийн зам уу? Энэ бүхэн ямар ч утгагүй! Ганц ч үг нь зүй зохистой биш! Энэ олон жилийн турш Бурханыг та нар ийм маягаар хуваасан, энэ нь үеэс үед илүү нарийн болж хуваагдсаар нэг Бурхан нь гурван Бурхан болж илт хуваагдах хэмжээнд очсон. Одоо хүний хувьд Бурханыг нэг болгон бүцаан нийлүүлэх ердөө боломжгүй, учир нь та нар Түүнийг хэтэрхий нарийн хуваасан! Хэтэрхий оройтохоос нь өмнө Миний шуурхай ажил хийгдээгүй бол хэр удаан ийм байдлаар ичгүүр сонжуургүйгээр үргэлжлүүлэх байсныг чинь хэлэхэд хэцүү юм! Бурханыг ийм байдлаар хуваасаар байвал Тэр яаж та нарын Бурхан хэвээр байж чадах юм бэ? Та нар Бурханыг таньж чадна гэж үү? Гарал үүслээ бас л олно гэж үү? Хэрвээ Би арай оройтож ирсэн бол “Эцэг, Хүү” Ехова Есүс хоёрыг Израиль руу буцаан илгээчихээд та нар өөрсдийгөө Бурханы нэг хэсэг гэцгээх байлаа. Азаар одоо бол эцсийн өдрүүд. Эцэстээ Миний удаан хүлээсэн энэ өдөр ирсэн ба ажлын энэ үе шатыг Өөрийн гараар хэрэгжүүлсний дараа л Би Бурханыг Өөрийг нь хуваадгийг чинь болиулсан. Хэрвээ тэгээгүй бол та нар нөхцөл байдлыг хурцатгаж, тэр ч бүү хэл өөрсдийн дунд байгаа бүх Сатаныг шүтэхээр ширээн дээрээ тавих байлаа. Энэ бол та нарын арга чарга! Бурханыг хуваах та нарын арга барил! Та нар одоо ч ингэсээр л байх уу? Би та нараас асууя: Хэдэн Бурхан байдаг вэ? Аль Бурхан нь та нарт аврал авчрах вэ? Та нарын үргэлж залбирдаг Бурхан чинь эхнийх нь үү, хоёр дахь нь уу, эсвэл гурав дахь нь уу? Алинд нь та нар үргэлж итгэдэг вэ? Эцэгт үү? Хүүд үү? Аль эсвэл Сүнсэнд үү? Чи хэнд нь итгэдгээ Надад хэл. Чи үг хэлэх бүрдээ Бурханд итгэдэг гэж хэлдэг хэдий ч үнэндээ уураг тархиндаа л итгэдэг! Та нарын зүрх сэтгэлд Бурхан ердөө байхгүй! Гэсэн ч та нарын оюун санаанд өдий төдий тийм Гурвалууд байдаг! Та нар санал нийлэхгүй байна гэж үү?

Хэрвээ ажлын гурван үе шатыг Гурвалын тухай энэхүү ухагдахууны дагуу үнэлбэл тус бүрийнх нь хийсэн ажил адилхан байгаагүй болохоор гурван Бурхан байх учиртай. Хэрвээ та нарын дундаас хэн нэг нь Гурвал үнэхээр оршдог гэж хэлбэл гурван бодгаль дахь энэ нэг Бурхан яг юу вэ гэдгийг тайлбарла. Ариун Эцэг гэж юу вэ? Хүү нь юу вэ? Ариун Сүнс гэж юу вэ? Ехова Ариун Эцэг үү? Есүс Хүү юу? Тэгвэл Ариун Сүнс юу вэ? Эцэг нь Сүнс биш гэж үү? Хүүгийн мөн чанар ч бас

Сүнс биш гэж үү? Есүсийн ажил нь Ариун Сүнсний ажил байгаагүй гэж үү? Тухайн үеийн Еховагийн ажлыг ч гэсэн Есүсийнхтэй адил Сүнс хийгээгүй гэж үү? Бурхан хэдэн Сүнстэй вэ? Чиний тайлбараар бол Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван бодгаль нь нэг; хэрвээ тийм бол гурван Сүнс байна, гэхдээ гурван Сүнс байна гэдэг нь гурван Бурхан байна гэсэн үг. Тэгвэл цор ганц жинхэнэ Бурхан байхгүй гэсэн үг; ийм Бурхан яаж Бурханы төрөлх мөн чанартай байж чадах юм бэ? Хэрвээ чи цорын ганц Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрвөл Тэр яаж хүүтэй байж, мөн эцэг байж чадах юм бэ? Эдгээр нь бүгдээрээ зүгээр л чиний үзэл биш гэж үү? Цорын ганц Бурхан байдаг, энэ Бурханд цорын ганц бодгаль байдаг, цорын ганц Бурханы Сүнс байдаг, яг л Библид бичсэнчлэн “Цорын ганц Ариун Сүнс, цорын ганц Бурхан байдаг.” Чиний ярьдаг Эцэг, Хүү оршдог эсэхээс үл хамааран, эцсийн эцэст цорын ганц Бурхан байдаг бөгөөд та нарын итгэдэг Эцэг, Хүү, Ариун Сүнсний мөн чанар бол Ариун Сүнсний мөн чанар юм. Өөрөөр хэлбэл, Бурхан бол Сүнс, гэхдээ Тэр махбод болж, хүмүүсийн дунд амьдарч, түүнчлэн бүх зүйлээс дээгүүр байж чаддаг. Түүний Сүнс бүхнийг-хамардаг бөгөөд хаа сайгүй оршдог. Тэрээр махбодод болон бүхий л орчлон ертөнцөд нэгэн зэрэг оршиж чадна. Бурхан бол цорын ганц жинхэнэ Бурхан гэж бүх хүн хэлдэг тул хэний ч хүслээр хуваагдашгүй ганцхан Бурхан байдаг! Бурхан бол цорын ганц Сүнс, цорын ганц бодгаль; тэр нь Бурханы Сүнс юм. Хэрвээ чиний хэлдгээр Эцэг, Хүү, Ариун Сүнс байсан бол Тэд гурван Бурхан биш гэж үү? Ариун Сүнс бол нэг зүйл, Хүү өөр зүйл бөгөөд Эцэг бас нэг өөр зүйл. Тэдний бодгаль өөр, бас мөн чанар нь ялгаатай тул Тэд яаж ганц Бурханы нэг хэсэг байж чадах юм бэ? Ариун Сүнс бол Сүнс; энэ нь хүний хувьд ойлгоход амархан. Хэрвээ тийм бол, Эцэг нь бүр ч Сүнс юм. Тэр хэзээ ч газар дээр буугаагүй, хэзээ ч махбод болоогүй; Тэр бол хүний зүрх сэтгэл дэх Ехова Бурхан бөгөөд Сүнс мөн гэдэг нь гарцаагүй. Тэгвэл Ариун Сүнс, Тэр хоёрын хоорондох харилцаа юу вэ? Эцэг, Хүүгийн хоорондох харилцаа юу? Эсвэл Ариун Сүнс болон Эцэгийн Сүнсний хоорондох харилцаа юу? Сүнс бүрийн мөн чанар адилхан уу? Эсвэл Ариун Сүнс нь Эцэгийн хэрэгсэл юм уу? Үүнийг хэрхэн тайлбарлаж болох вэ? Тэгвэл Хүү болон Ариун Сүнсний хоорондох харилцаа юу вэ? Энэ нь хоёр Сүнсний хоорондох харилцаа юу, эсвэл хүн, Сүнс хоёрын хоорондох харилцаа юу? Эдгээр нь бүгд ямар ч тайлбаргүй асуудлууд юм! Хэрвээ Тэд бүгд нэг Сүнс юм бол гурван бодгалийн тухай яриа байх учиргүй, учир нь Тэд нэг Сүнсийг эзэмшдэг билээ. Хэрвээ Тэд өөр өөр бодгалиуд байсан бол Тэдний Сүнс хүч чадлаараа ялгаатай байх байсан ба Тэд нэг Сүнс байж ердөө чадахгүй. Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай энэ үзэл баримтлал хамгийн утгагүй! Энэ нь Бурханыг хэсэглэж, тус бүрдээ байр суурьтай, Сүнстэй гурван бодгаль болгон хуваадаг; тэгвэл Тэр яаж ганц Сүнс, ганц Бурхан байж чадах юм бэ? Надад хэл дээ, тэнгэр, газар болон бүх зүйлийг Эцэг бүтээсэн үү, Хүү бүтээсэн үү, эсвэл Ариун Сүнс бүтээсэн үү? Тэд бүгдээрээ хамт бүтээсэн гэж зарим хүн хэлдэг. Тэгвэл хүн төрөлхтнийг хэн золин аварсан бэ? Ариун Сүнс үү, Хүү юү, эсвэл Эцэг үү? Хүү хүн төрөлхтнийг золин аварсан гэж зарим нь хэлдэг.

Тэгвэл мөн чанартаа Хүү нь хэн юм бэ? Тэр бол бие махбодтой болсон Бурханы Сүнс биш гэж үү? Бие махбодтой болсон Бурхан нь, бүтээгдсэн хүний өнцгөөс тэнгэр дэх Бурханыг Эцэг гэж дуудаж байсан. Есүс Ариун Сүнснээс олдож төрсөн гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Түүний дотор Ариун Сүнс байдаг; чи юу ч хэлсэн бай, Тэрээр тэнгэр дэх Бурхантай нэг юм, учир нь Тэр бол бие махбодтой болсон Бурханы Сүнс билээ. Хүүгийн талаарх энэхүү үзэл санаа зүгээр л худал юм. Ганц Сүнс бүх ажлыг хэрэгжүүлсэн; Бурхан Өөрөө буюу Бурханы Сүнс л Өөрийн ажлыг хэрэгжүүлдэг. Бурханы Сүнс гэж хэн бэ? Энэ нь Ариун Сүнс биш гэж үү? Есүст ажилладаг Ариун Сүнс биш гэж үү? Хэрвээ ажлыг Ариун Сүнс (өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс) хэрэгжүүлээгүй бол Түүний ажил Бурханыг Өөрийг нь төлөөлж чадах байсан уу? Есүс залбирахдаа тэнгэр дэх Бурханыг Эцэг хэмээн дуудаж байсан нь зөвхөн бүтээгдсэн хүний өнцгөөс, мөн Бурханы Сүнс эгэл, хэвийн махбод өмсөж, бүтээгдсэн зүйлийн гадаад бүрхүүлтэй болсон учраас л тэгсэн юм. Түүний дотор Бурханы Сүнс байсан ч гэсэн гадаад төрх нь хэвийн хүнийх байсан; өөрөөр хэлбэл, Есүсийг Өөрийг нь оролцуулаад бүх хүний хэлдгээр Тэр “хүний Хүү” болсон байлаа. Хүний Хүү гэж дуудагдаж байсныг нь харгалзан үзвэл, Тэрээр эгэл жирийн хүмүүсийн хэвийн гэр бүлд төрсөн хүн (эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, ямартай ч хүний гадаад төрхтэй) байсан юм. Тиймээс Есүс тэнгэр дэх Бурханыг Эцэг хэмээн дуудсан нь анх та нар Түүнийг Эцэг гэж дуудсантай адил; Тэрээр бүтээгдсэн хүний өнцгөөс ингэсэн. Та нарт цээжлүүлэх гэж Есүсийн заасан Эзэний Залбирлыг та нар санаж байна уу? “Тэнгэр дэх бидний Аав аа…” Тэнгэр дэх Бурханыг Эцэгийн нэрээр дуудахыг Тэр бүх хүнээс шаардсан. Тэр ч гэсэн Бурханыг Аав гэж дуудсан ба та бүхэнтэй адил байр сууринд зогсож байгаа хүний өнцгөөс ингэсэн юм. Нэгэнт та нар тэнгэр дэх Бурханыг Эцэгийн нэрээр дууддаг учраас Есүс Өөрийгөө та нартай адил байр сууринд байгаагаар, мөн Бурханы сонгосон газар дээрх хүн (өөрөөр хэлбэл, Бурханы Хүү) мэтээр үзжээ. Хэрвээ та нар Бурханыг “Эцэг” хэмээн дуудвал, энэ нь бүтээгдсэн зүйл гэдгээс чинь болж байгаа бус уу? Газар дээрх Есүсийн эрх мэдэл хэчнээн агуу байсан ч цовдлолоос өмнө Тэр бол зүгээр л Ариун Сүнсээр (өөрөөр хэлбэл, Бурханаар) удирдуулсан хүний Хүү байсан бөгөөд газар дээрх бүтээгдсэн зүйлсийн нэгэн байсан, учир нь Тэр Өөрийн ажлыг хараахан биелүүлээгүй байсан юм. Тиймээс, тэнгэр дэх Бурханыг Эцэг хэмээн дуудсан нь гагцхүү Түүний даруу зан, дуулгавартай байдал байлаа. Тэрээр Бурханыг (өөрөөр хэлбэл, тэнгэр дэх Сүнсийг) тийм байдлаар дуудаж байсан нь Тэр бол тэнгэр дэх Бурханы Сүнсний Хүү гэдгийг нотолдоггүй. Харин ч Тэр өөр бодгаль байсан юм биш, зүгээр л Түүний харах өнцөг өөр байсан юм. Өөр өөр бодгалийн оршин тогтнол гэдэг нь гажууд онол юм! Цовдлогдохоосоо өмнө Есүс махан биеийн хязгаарлалтад баригдсан хүний Хүү байсан бөгөөд Сүнсний эрх мэдлийг бүрэн эзэмшээгүй. Тийм учраас Тэр бүтээгдсэн зүйлийн өнцгөөс Эцэг Бурханы хүслийг эрж хайж л чадсан юм. Тэрээр Гетсеманид: “Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” хэмээн гурвантаа залбирсантай адил. Загалмай дээр цовдлогдохоосоо өмнө

Тэр иудейчүүдийн Хаан байсан; Тэрээр алдрын бие биш, харин Христ, хүний Хүү байлаа. Тийм учраас бүтээгдсэн зүйлийн өнцгөөс Тэрээр Бурханыг Эцэг гэж дуудсан юм. Тэгэхээр чи, Бурханыг Эцэг хэмээн дууддаг бүхэн нь Хүү юм гэж хэлж болохгүй. Хэрвээ тийм байсан бол Есүс та нарт Эзэний Залбирлыг заамагц та нар бүгдээрээ Хүү болох бус уу? Хэрвээ та нар одоо ч үнэмшихгүй байгаа бол Надад хэл дээ, та нарын Эцэг гэж дууддаг нэгэн чинь хэн бэ? Хэрвээ та нар Есүсийг хэлж байгаа бол Есүсийн Эцэг та нарын хувьд хэн бэ? Есүсийг явж одсоны дараа Эцэг, Хүү гэх энэ санаа байхаа больсон. Энэхүү санаа нь Есүсийг махбод болсон байх тэр жилүүдэд л тохиромжтой байв; бусад бүх нөхцөл байдалд та нар Бурханыг Эцэг хэмээн дуудах үед, энэ нь бүтээлийн Эзэн болон бүтээгдсэн зүйлийн хоорондын харилцаа байдаг. Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвалын тухай энэхүү санаа хэзээ ч байж болохгүй; энэ нь эрин үеүдэд ховорхон харагддаг гажууд онол бөгөөд оршин байдаггүй!

Энэ нь Эхлэл дэх Бурханы үгийг ихэнх хүнд сануулж магадгүй: “Бид өөрсөдтэйгээ адилаар, өөрсдийн дүр төрхөөр хүнийг бүтээцгээе” (Эхлэл 1:26). “Бид хүнийг Өөрсдийнхөө дүрээр бүтээе” гэж Бурханы хэлснийг авч үзвэл “Бид” гэдэг нь хоёр буюу түүнээс олон гэдгийг илэрхийлж байна; нэгэнт Тэр “Бид” гэж хэлсэн учраас зөвхөн ганц Бурхан байдаггүй. Ийм маягаар хүн өөр өөр бодгалийг хийсвэрээр бодож эхэлсэн бөгөөд эдгээр үгээс Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай санаа төрсөн. Тэгвэл Эцэг ямархуу вэ? Хүү ямархуу вэ? Мөн Ариун Сүнс ямархуу вэ? Өнөөдрийн хүн төрөлхтөн энэ гурвыг нийлүүлсэн нэгний дүрээр бүтээгдсэн юм гэж үү? Тэгвэл хүний дүр Эцэг, Хүү, эсвэл Ариун Сүнснийхтэй адилхан уу? Бурханы эдгээр бодгалийн алиных нь дүрээр хүн бүтээгдсэн бэ? Хүний энэ санаа зүгээр л буруу бөгөөд ямар ч утгагүй! Энэ нь ердөө нэгэн Бурханыг хэд хэдэн Бурхан болгон хувааж л чадна. Дэлхийн бүтээлийн дараагаар хүн төрөлхтөн бүтээгдсэний хойно Мосе Эхлэлийг бичсэн. Хамгийн анх дэлхий ертөнц бий болох үед Мосе байгаагүй. Мосе Библийг их сүүлд бичсэн юм, тэгвэл тэнгэр дэх Бурханы юу хэлснийг тэр яаж мэдсэн байх юм бэ? Бурхан энэ дэлхийг хэрхэн бүтээсэн талаар тэр огт мэдэхгүй. Библийн Хуучин Гэрээнд Эцэг, Хүү, Ариун Сүнсний талаар огт дурддаггүй, зөвхөн цорын ганц жинхэнэ Бурхан, Ехова Өөрийн ажлыг Израильд хийж буй тухай дурддаг. Эрин үе өөрчлөгдөхийн хэрээр Тэр өөр өөр нэрээр нэрлэгдсэн, гэхдээ нэр бүхэн нь өөр бодгалийг хэлдэг гэдгийг энэ нь нотолж чадахгүй. Хэрвээ тийм байсан бол Бурханд тоо томшгүй олон бодгаль байх байсан бус уу? Хуучин Гэрээнд бичигдсэн зүйл бол Еховагийн ажил, Хуулийн эрин үед эхлүүлсэн Бурханы Өөрийн ажлын үе шат юм. Энэ нь Бурханы ажил байсан ба Түүнийг ярих үед бий болж, Түүнийг тушаах үед биелж байсан. Тэр бол ажлаа гүйцэтгэхээр ирсэн Эцэг гэж Ехова хэзээ ч хэлээгүй, эсвэл хүн төрөлхтнийг золин аврахын тулд Хүү ирэх тухай хэзээ ч зөгнөөгүй. Есүсийн цаг үеийн тухайд гэвэл, бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд Бурхан махбод болсон гэж л хэлсэн байдаг, харин Хүү ирсэн гэж хэлээгүй. Эрин үеүд адилгүй бөгөөд Бурханы Өөрийн хийдэг ажил ч бас ялгаатай

байдаг учраас Тэр Өөрийн ажлыг өөр өөр хүрээнд хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Ийм маягаар, Түүний төлөөлдөг ялгамж чанар ч бас ялгаатай байдаг. Ехова бол Есүсийн Эцэг гэж хүн боддог, гэхдээ үнэндээ үүнийг Есүс хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд “Бид Эцэг, Хүү хэмээн хэзээ ч ялгардаггүй; тэнгэр дэх Эцэг Бид хоёр нэг юм. Эцэг Миний дотор, Би Эцэгийн дотор байдаг; Хүүг харах үедээ хүн тэнгэрлэг Эцэгийг харж байгаа юм” хэмээн хэлсэн. Эцсийн эцэст, Эцэг ч бай, эсвэл Хүү ч бай Тэд нэг Сүнс бөгөөд тусдаа бодгаль болон хуваагддаггүй. Хүн тайлбарлахаар оролдмогц, өөр өөр бодгалийн тухай санаа, мөн түүнчлэн Эцэг, Хүү, Ариун Сүнсний хоорондын харилцаа нь асуудлыг төвөгтэй болгодог. Хүн тусдаа бодгалиудын тухай ярих үед, энэ нь Бурханы материаллаг болгож байгаа бус уу? Хүн бодгалийг нь нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар гэж ч эрэмбэлдэг; эдгээр нь бүгд хүний төсөөлөл, лавлагаа болох ямар ч үнэ цэнгүй бөгөөд туйлын бодит бус! Хэрвээ чи түүнээс: “Хэдэн Бурхан байдаг вэ?” гэж асуувал тэр, Бурхан бол Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвал буюу ганц жинхэнэ Бурхан юм гэж хэлэх болно. Хэрвээ чи цааш нь: “Эцэг хэн бэ?” гэж асуувал тэрээр: “Эцэг бол тэнгэр дэх Бурханы Сүнс; Тэр бүхнийг хариуцдаг ба тэнгэрийн Эзэн юм” гэж хэлнэ. “Тэгвэл Ехова Сүнс мөн үү?” гэхэд тэрээр: “Тийм!” гэж хариулна. Хэрвээ дараа нь чи түүнээс “Хүү хэн бэ?” гэж асуувал мэдээж Есүс бол Хүү гэх болно. “Тэгвэл Есүсийн түүх юу вэ? Тэр хаанаас ирсэн бэ?” гэхэд тэр ингэж хэлнэ: “Есүс Ариун Сүнснээс олдож Мариагаас төрсөн.” Тэгвэл Түүний мөн чанар ч бас Сүнс биш гэж үү? Түүний ажил ч бас Ариун Сүнсний ажлын төлөөлөл биш гэж үү? Ехова бол Сүнс, Есүсийн мөн чанар ч бас адилхан. Одоо эцсийн өдрүүдэд, энэ нь мөн л Сүнс юм гэдгийг хэлэх бүр ч шаардлагагүй; Тэд яаж өөр өөр бодгаль байх юм бэ? Ердөө л Бурханы Сүнс өөр өөр өнцгөөс Сүнсний ажлыг хэрэгжүүлж байгаа хэрэг биш гэж үү? Тийм болохоор бодгалиудын хооронд ялгаа байдаггүй. Есүс Ариун Сүнснээс олдсон, Түүний ажил яг тэр Ариун Сүнснийх байсан нь маргаангүй. Гүйцэтгэсэн ажлынхаа эхний үе шатанд Ехова махбод болоогүй, бас хүнд ч харагдаагүй. Иймээс хүн хэзээ ч Түүний гадаад төрхийг хараагүй. Тэр хэчнээн агуу, хэчнээн өндөр байсан нь хамаагүй, хүнийг анх бүтээсэн Бурхан Өөрөө буюу Сүнс хэвээр байсан. Өөрөөр хэлбэл, Тэрээр Бурханы Сүнс байлаа. Үүлэн дундаас хүнтэй ярих үедээ Тэр ердөө л Сүнс байсан ба Түүний гадаад төрхийг хэн ч нүдээр үзээгүй; зөвхөн Нигүүлслийн эрин үед Бурханы Сүнс махбодод ирж, Иудейд бие махбодтой болоход л хүн бие махбодтой болсон Бурханыг иудей хүний дүрээр анх харсан. Түүнд Еховагийн гэх юу ч байгаагүй. Гэсэн ч Тэр Ариун Сүнснээс олдсон, өөрөөр хэлбэл, Еховагийн Өөрийн Сүнснээс олдсон бөгөөд Есүс мөн л Бурханы Сүнсний биелэл болон төрсөн билээ. Ариун Сүнс Есүс дээр тагтаа мэт буухыг л хүн анх харсан; энэ нь ганцхан Есүсийн Сүнс байгаагүй, харин ч Ариун Сүнс байсан юм. Тэгвэл Есүсийн Сүнсийг Ариун Сүнснээс салгаж болох уу? Хэрвээ Есүс нь Есүс, Хүү бөгөөд Ариун Сүнс нь Ариун Сүнс юм бол Тэд яаж нэг байж чадах юм бэ? Хэрвээ тийм байсан бол ажлыг хэрэгжүүлж чадахгүй байх байв. Есүсийн доторх Сүнс, тэнгэр дэх Сүнс болон Еховагийн Сүнс

бүгд нэг юм. Үүнийг Ариун Сүнс, Бурханы Сүнс, долоо дахин эрчимжсэн Сүнс, бүгдийг хамарсан Сүнс гэж нэрлэж болно. Бурханы Сүнс их ажил гүйцэтгэж чадна. Тэр дэлхийг бүтээж, бас үерээр газар дэлхийг устгаж чадна; Тэр бүх хүн төрөлхтнийг золин аварч чадна, түүнчлэн бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бас устгаж чадна. Энэ ажлыг бүгдийг нь Бурхан Өөрөө хийдэг бөгөөд Түүний оронд Бурханы өөр ямар ч бодгаль хийж чадахгүй байх байв. Түүний Сүнсийг Ехова, Есүс, түүнчлэн Төгс Хүчит гэж нэрлэж болно. Тэр бол Эзэн бөгөөд Христ юм. Тэр бас хүний Хүү болж чадна. Тэр тэнгэрт, бас газарт байдаг; Тэр орчлон ертөнцөөс дээш өндөрт байдаг бөгөөд олон түмний дунд байдаг. Тэр бол тэнгэр, газрын цорын ганц Эзэн билээ! Бүтээлийн цаг үеэс эхлээд одоог хүртэл энэ ажлыг Бурханы Өөрийн Сүнс хийсээр ирсэн. Тэнгэр дэх ажил ч бай, эсвэл махбод дахь ажил бай бүгдийг нь Түүний Сүнс хийдэг. Тэнгэр дэх ч бай, эсвэл газар дахь ч бай бүх бүтээл Түүний төгс хүчит гарын алганд байдаг; энэ бүхэн нь Бурханы Өөрийн ажил бөгөөд Түүний оронд өөр хэн ч хийж чадахгүй. Тэнгэрт Тэр бол Сүнс, бас Бурхан Өөрөө; хүмүүсийн дунд Тэр махбод боловч Бурхан Өөрөө хэвээр. Хэдэн зуун мянган нэрээр нэрлэж болох ч Тэр Өөрөө хэвээр бөгөөд Түүний Сүнсний шууд илэрхийлэл юм. Түүний цовдлолоор дамжин ирсэн бүх хүн төрөлхтний золин аврал нь Түүний Сүнсний шууд ажил байсан бөгөөд эцсийн өдрүүдэд бүх улс орон, газар нутагт илгээх тунхаглал ч Түүний Сүнсний шууд ажил. Бурханыг цаг ямагт төгс хүчит, ганц жинхэнэ Бурхан, бүгдийг хамарсан Бурхан Өөрөө гэж л нэрлэж болно. Тусдаа бодгалиуд оршин тогтнодоггүй, Эцэг, Хүү, Ариун Сүнс хэмээх санаа бүр ч оршдоггүй. Тэнгэрт болон газарт цорын ганц Бурхан байдаг!

Бурханы удирдлагын төлөвлөгөө зургаан мянган жил үргэлжилдэг бөгөөд Түүний ажлын ялгаанд үндэслэн гурван эрин үед хуваагддаг: Эхний эрин үе нь Хуучин Гэрээний Хуулийн эрин үе; хоёр дахь нь Нигүүлслийн эрин үе; гурав дахь нь эцсийн өдрүүдийн Хаанчлалын эрин үе юм. Эрин үе болгонд өөр өөр ялгамж чанарыг төлөөлдөг. Энэ нь зөвхөн ажлын ялгаанаас буюу ажлын шаардлагаас болдог. Хуулийн эрин үе дэх ажлын эхний үе шат Израильд явагдсан ба золин авралын ажлыг төгсгөсөн хоёр дахь үе шат нь Иудейд хийгдсэн. Золин авралын ажлын төлөө Есүс Ариун Сүнснээс олдож, цорын ганц Хүү болон төрсөн. Энэ бүхэн нь ажлын шаардлагаас болсон юм. Эцсийн өдрүүдэд Бурхан Өөрийн ажлыг Харь үндэстнүүдэд өргөжүүлж, тэндхийн хүмүүсийг байлдан дагуулахыг хүсдэг, ингэснээр Түүний нэр тэдний дунд агуу болж болох юм. Тэрээр бүх үнэнийг ойлгож, ороход нь хүнийг залж чиглүүлэхийг хүсдэг. Энэ бүх ажлыг нэг Сүнс хийдэг. Хэдий Тэр өөр өөр өнцгөөс ингэж хийдэг боловч ажлын шинж чанар болон зарчим адилхан хэвээр үлддэг. Тэдний гүйцэтгэсэн ажлын зарчим, шинж чанарыг ажигламагцаа энэ бүхнийг нэг Сүнс хийсэн гэдгийг чи мэднэ. Гэсэн ч зарим хүн: “Эцэг бол Эцэг; Хүү бол Хүү; Ариун Сүнс бол Ариун Сүнс бөгөөд эцэстээ Тэд нэг болно” хэмээн хэлсээр байж магадгүй. Тэгвэл чи Тэднийг хэрхэн нэг болгох ёстой вэ? Эцэг, Ариун Сүнс хоёрыг яаж нэг болгож чадах вэ? Хэрвээ Тэд угаасаа хоёр

байсан бол Тэднийг яаж ч нийлүүлсэн хамаагүй хоёр хэсэг хэвээр үлдэхгүй гэж үү? Тэднийг нэг болгох тухай ярих нь, нэг бүхэл болгохын тулд хоёр тусдаа хэсгийг нийлүүлж байгаа хэрэг биш гэж үү? Гэхдээ бүхэл болгуулахаасаа өмнө Тэд хоёр хэсэг байгаагүй гэж үү? Сүнс бүрд өөр өөр мөн чанар байдаг бөгөөд хоёр Сүнсийг ганц болгож болохгүй. Сүнс бол материаллаг зүйл биш, материаллаг ертөнц дээрх юутай ч адилгүй. Хүний үздэгээр, Эцэг нь нэг Сүнс, Хүү өөр Сүнс, Ариун Сүнс бас нэг Сүнс юм, тэгээд нэг бүхэл болгохын тулд гурван Сүнсийг гурван аягатай ус шиг хольж болно. Тэгвэл энэ гурав нэг болох бус уу? Энэ бол гарцаагүй эндүү ташаа, утгагүй тайлбар юм! Энэ нь Бурханыг хувааж байгаа хэрэг биш үү? Яаж Эцэг, Хүү, Ариун Сүнсийг нэг болгож болох юм бэ? Тэд бол тус бүрдээ өөр шинж чанартай гурван хэсэг биш гэж үү? “Есүс бол Түүний хайртай Хүү гэж Бурхан тов тодорхой хэлээгүй гэж үү?” хэмээн хэлдэг хүмүүс бий. Есүс бол Бурханы хайртай Хүү, Түүнийг Тэр ихэд таалдаг гэж Бурхан Өөрөө гарцаагүй хэлсэн. Тэр нь, Бурхан Өөрийгөө гэрчилж байсан хэрэг боловч ердөө өөр өнцгөөс буюу тэнгэр дэх Сүнсний өнцгөөс бие махбодтой болсон Өөртөө гэрчлэл хийж байсан хэрэг юм. Есүс бол Түүний тэнгэр дэх Хүү биш, бие махбодтой болсон Бурхан юм. Чи ойлгов уу? “Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа” хэмээх Есүсийн үг нь Тэд бол нэг Сүнс гэдгийг илтгэдэггүй гэж үү? Бие махбодтой болсноос болж Тэд тэнгэр, газрын хоорондтусгаарлагдаагүй гэж үү? Үнэндээ Тэд нэг хэвээр байгаа; ямар ч байсан энэ нь Бурхан зүгээр л Өөрийгөө гэрчилж байгаа хэрэг. Эрин үеүдийн өөрчлөлт, ажлын шаардлага болон удирдлагын төлөвлөгөөнийх нь ялгаатай үе шатуудаас шалтгаалан хүний Түүнийг дууддаг нэр ч бас өөр өөр байдаг. Ажлын эхний үе шатыг хэрэгжүүлэхээр ирэхдээ Тэр зүгээр л Ехова гэж нэрлэгддэг, израильчуудын хоньчин байсан. Хоёр дахь үе шатанд бие махбодтой болсон Бурхан зөвхөн Эзэн, Христ гэж нэрлэгдэж байв. Гэхдээ тухайн үед, Тэр бол Бурханы хайртай Хүү гэж тэнгэр дэх Сүнс хэлсэн бөгөөд Түүнийг Бурханы цорын ганц Хүү гэж огт дурдаагүй. Энэ нь ердөө тохиолдоогүй. Бурхан яаж ганц хүүхэдтэй байх юм бэ? Тэгвэл Бурхан хүн болчихгүй гэж үү? Тэр бие махбодтой болсон байсан учраас Түүнийг Бурханы хайртай Хүү гэж дуудсан бөгөөд эндээс Эцэг, Хүүгийн хоорондын харилцаа гарч ирсэн. Энэ нь зүгээр л тэнгэр, газрын хоорондох тусгаарлалтаас болсон юм. Есүс махбодын өнцгөөс залбирсан. Тэр тийм хэвийн хүн чанартай махбод өмссөн байсан учраас махбодын өнцгөөс Тэрээр: “Миний гадаад бүрхүүл бүтээгдсэн зүйлийнх. Би энэ дэлхийд ирэхийн тулд махбод өмссөн тул тэнгэрээс холын хол байна” гэж хэлсэн юм. Энэ шалтгааны улмаас Тэр зөвхөн махбодын өнцгөөс л Эцэг Бурханд залбирч байв. Энэ нь Түүний үүрэг байсан бөгөөд бие махбодтой болсон Бурханы Сүнсний эзэмших ёстой зүйл байлаа. Махбодын өнцгөөс Эцэгт залбирч байснаас нь болоод Түүнийг Бурхан биш гэж хэлж болохгүй. Хэдий Бурханы хайртай Хүү гэж дуудагдаж байсан ч Тэр бол Бурхан Өөрөө хэвээр юм, учир нь Тэр бол бие махбодтой болсон Сүнс бөгөөд Түүний мөн чанар бас л Сүнс юм. Хэрвээ Тэр Бурхан Өөрөө байсан юм бол яагаад залбирсан юм бэ гэж хүмүүс гайхдаг.

Үүний учир нь, Тэр бол тэнгэр дэх Сүнс биш, харин бие махбодтой болсон Бурхан, махбод дотор амьдарч байгаа Бурхан байсан билээ. Хүний харж байгаагаар, Эцэг, Хүү, Ариун Сүнс нь бүгд Бурхан. Зөвхөн энэ гурвыг нэг болгосон үед л нэг жинхэнэ Бурхан гэж үзэж болох ба ийм маягаар Түүний хүч чадал ер бусын агуу юм. Ийм маягаар л Тэр бол долоо дахин эрчимжсэн Сүнс мөн гэж хэлдэг хүмүүс бий. Ирснийхээ дараа Хүү залбирах үед Түүний залбирсан зүйл нь тэрхүү Сүнс байсан. Үнэндээ Тэр бүтээгдсэн зүйлийн өнцгөөс л залбирч байлаа. Махбод бүрэн гүйцэд биш учраас Тэр махбодод ирэх үедээ бүрэн гүйцэд байгаагүй, олон сул талтай байсан, мөн Өөрийн ажлыг махбодоор гүйцэтгэхэд Түүнд ихээхэн төвөг учирсан. Тийм учраас Тэр цовдлогдохоосоо өмнө Эцэг Бурханд гурвантаа залбирсан, түүнчлэн тэрнээс өмнө ч олон удаа залбирсан. Тэр шавь нарынхаа дунд залбирсан; уулан дээр ганцаараа залбирсан; загасчны завин дээр залбирсан; үй олон хүмүүсийн дунд залбирсан; талх хувааж байхдаа залбирсан; мөн бусдыг ерөөхдөө залбирсан билээ. Яагаад тэгсэн бэ? Тэрээр Сүнсэнд хандаж залбирсан; Тэр махбодын өнцгөөс Сүнсэнд, тэнгэр дэх Бурханд залбирч байсан. Тиймээс хүний үзэл бодлоор бол, ажлын тэрхүү үе шатанд Есүс Хүү болсон юм. Гэхдээ энэ үе шатанд Тэр залбирдаггүй. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, Түүний авчирдаг зүйл нь үгийн ажил бөгөөд үгийн шүүлт, гэсгээлт юм. Тэр залбирах хэрэггүй, Түүний үйлчлэл бол үг хэлэх явдал билээ. Тэр загалмайд цовдлогдохгүй бөгөөд хүн Түүнийг эрх мэдэлтнүүдэд барьж өгөхгүй. Тэр зүгээр л Өөрийн ажлыг хэрэгжүүлдэг. Есүс залбирч байх үедээ, тэнгэрийн хаанчлал бууж ирэхийн төлөө, Эцэгийн хүсэл биелэгдэхийн төлөө болон хожмын ажлын төлөө Эцэг Бурханд залбирсан. Энэ үе шатанд тэнгэрийн хаанчлал аль хэдийн бууж ирсэн тул залбирах хэрэг Түүнд байгаа гэж үү? Түүний ажил бол эрин үеийг төгсгөх явдал бөгөөд цаашид шинэ эрин үе гэж байхгүй, иймд дараагийн үе шатны төлөө залбирах хэрэг байгаа юу? Үгүй байх аа!

Хүний тайлбарт олон зөрчилдөөн байдаг. Үнэндээ, эдгээр нь бүгд хүний үзэл юм; та бүхэн цааш нь нарийвчлан судлалгүйгээр тэдгээрийг үнэн зөв хэмээн итгэдэг. Гурвал Бурхан гэх ийм санаа нь хүний үзэл гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Хүний ямар ч мэдлэг бүрэн гүйцэд биш. Үүнд үргэлж хольц байдаг ба хүнд хэтэрхий олон санаа бий; бүтээгдсэн зүйл Бурханы ажлыг тайлбарлаж ер чадахгүй гэдгийг энэ нь харуулдаг. Хүний оюун санаанд хэтэрхий их зүйл байдаг ба эдгээр нь бүгд үнэнтэй зөрчилддөг логик болон бодлоос үүсэн гардаг. Чиний логик Бурханы ажлыг бүрэн гүйцэд задлан шинжилж чадах уу? Еховагийн бүх ажлыг нэвт харж чадах уу? Энэ бүхнийг нэвт шувт хардаг нь хүн чи юү, эсвэл мөнхөөс мөнхөд харж чаддаг нэгэн нь Бурхан Өөрөө юү? Мөнхийн эрт дээр үеэс үүрдийн мөнхийг харж чаддаг нь чи юү, эсвэл мөнхийн эрт дээр үеэс ирээдүйн мөнхийг хүртэл харж чаддаг нь Бурхан уу? Чи юу гэх вэ? Бурханыг тайлбарлахад чи яаж тохирох юм бэ? Чиний тайлбар юунд үндэслэдэг вэ? Чи Бурхан уу? Тэнгэр, газар болон бүх зүйлийг Бурхан Өөрөө бүтээсэн. Чи үүнийг хийгээгүй, тэгвэл чи яагаад буруу тайлбар өгч

байгаа юм бэ? Одоо чи гурвал Бурханд итгэсээр байна уу? Ингэх нь хэтэрхий ядаргаатай гэж бодохгүй байна уу? Гурав биш ганц Бурханд итгэх нь чиний хувьд хамгийн сайн байх болно. Хөнгөн байх нь хавьгүй дээр, учир нь Эзэний ачаа хөнгөн билээ.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 3

Та нар бие даан амьдрах чадвартай байж, Бурханы үгийг өөрсдөө идэж ууж, Бурханы үгийг биечлэн туулж, бусдын удирдлагагүйгээр хэвийн сүнслэг амьдралаар амьдарч чаддаг байх ёстой. Та нар амьдарч, жинхэнэ туршлага руу орж, жинхэнэ мэдлэг ухаан олж авахын тулд Бурханы өнөөдөр хэлдэг үгэнд найдаж чаддаг байх ёстой. Тэр үед л та нар бат зогсож чадна. Өнөөдөр олон хүн хожмын гай зовлон, шалгалтуудыг бүрэн ойлгодоггүй. Ирээдүйд зарим хүн гай зовлон туулж, зарим нь шийтгэл амсана. Энэхүү шийтгэл бүр ч хатуу ширүүн байна; энэ нь баримтуудын ирэлт байх болно. Өнөөдөр чиний туулдаг, хийдэг, илэрхийлдэг бүхэн хожмын шалгалтуудын суурийг тавьдаг ба хамгийн наад зах нь чи бие даан амьдарч чаддаг байх ёстой. Өнөөдөр чуулган дахь олон хүний нөхцөл байдал ерөнхийдөө дараах байдалтай байдаг: Хэрвээ чуулганы ажлыг хийх удирдагчид, ажилчид байгаа бол тэд баярладаг бөгөөд байхгүй бол баяр хөөргүй байдаг; тэд чуулганы ажилд ч, өөрсдийн сүнслэг амьдралд ч анхаарал хандуулдаггүй ба тэдэнд өчүүхэн төдий ч ачаа байдаггүй—яг Ханхао шувуутай[a] адил. Үнэнийг хэлэхэд, олон хүний хувьд Миний ажил бол зүгээр л байлдан дагуулалтын ажил юм, учир нь олон хүн үндсэндээ төгс болгуулах үнэ цэнгүй байдаг. Хүмүүсээс тун цөөхөн нь л төгс болгуулж чадна. Хэрвээ эдгээр үгийг сонсчхоод, “Бурханы хийдэг ажил хүмүүсийг байлдан дагуулахын төлөө л байдаг юм чинь би хааш яаш л дагана” гэж чи боддог бол тийм хандлага яаж хүлээн зөвшөөрч болохуйц байх юм бэ? Хэрвээ чи үнэхээр мөс чанартай бол чамд ачаа болон хариуцлагын мэдрэмж байх ёстой. Чи ингэж хэлэх ёстой: “Би байлдан дагуулагдах эсвэл төгс болгуулах эсэхээ тоохгүй, гэхдээ би гэрчлэлийн энэ алхмыг зүй зохистой хийх ёстой.” Бурханы бүтээл болохын хувьд хүн Бурханаар бүрэн байлдан дагуулагдаж чадна, эцэст нь хүн Бурханыг хайрладаг зүрх сэтгэлээрээ Бурханы хайрыг хариулж, өөрийгөө Бурханд бүрмөсөн зориулснаар Бурханыг хангалуун байлгаж чаддаг. Энэ бол хүний хариуцлага, энэ нь хүний биелүүлэх учиртай үүрэг, хүний үүрэх учиртай ачаа бөгөөд хүн энэ даалгаврыг гүйцэтгэх ёстой. Зөвхөн тэр үед л тэрээр Бурханд үнэхээр итгэнэ. Өнөөдөр чуулганд хийдэг зүйл чинь чиний хариуцлагын хэрэгжилт

[a] Ханхао шувууны түүх нь шоргоолж, царцаа хоёрын тухай Эзопын ёгт үлгэртэй тун адилхан. Ханхао шувуу өөрийн хөрш, алаг шаазгайн олон удаагийн анхааруулгыг үл харгалзан, цаг агаар дулаахан байх зуур үүрээ барихын оронд унтахыг илүүд үздэг. Өвөл болоход уг шувуу хөлдөж үхдэг.

үү? Энэ нь ачаа үүрсэн эсэхээс чинь хамаардаг, мөн мэдлэгээс чинь хамаардаг. Энэ ажлыг туулахад хэрвээ хүн байлдан дагуулагдсан агаад жинхэнэ мэдлэгтэй бол өөрийн хэтийн ирээдүй, хувь заяаг үл харгалзан дуулгавартай байж чадна. Ийм маягаар Бурханы агуу ажил бүхэлдээ биелнэ, учир нь энэ хүмүүс үүнээс илүүг хийх чадваргүй бөгөөд илүү өндөр шаардлагыг хэрэгжүүлж чадахгүй. Гэсэн ч ирээдүйд зарим хүн төгс болгуулна. Тэдний хэв чанар сайжирч, сүнсэндээ илүү гүн гүнзгий мэдлэгтэй болж, амь нь өснө… Гэхдээ зарим нь үүнд хүрч огт чадахгүй байх тул аврагдаж чадахгүй. Тэд аврагдаж чадахгүй гэж Миний хэлсэнд шалтгаан бий. Ирээдүйд зарим нь байлдан дагуулагдах болно, зарим нь таягдан хаягдана, зарим нь төгс болгуулна, зарим нь ашиглагдана—иймээс зарим нь гай зовлон амсаж, зарим нь шийтгэл (байгалийн гамшиг болон хүний бий болгосон гай гамшгийн аль алийг) туулна, зарим нь таягдан хаягдаж, зарим нь амьд үлдэнэ. Ийнхүү бүгд төрлийнхөө дагуу ангилагдаж, бүлэг тус бүр нь тухайн хүний төрлийг төлөөлнө. Бүх хүн таягдан хаягдахгүй, мөн бүх хүн төгс болгуулахгүй. Учир нь Хятад хүмүүсийн хэв чанар маш дорд бөгөөд Паул шиг өөрийн ухамсартай хүн тэдний дунд ердөө хэдхэн байдаг. Энэ хүмүүсийн дундаас цөөхөн нь Петрийнх шиг Бурханыг хайрлах шийдвэртэй, эсвэл Иовынх шиг итгэлтэй байдаг. Давид шиг хэмжээнд Еховаг хүндэлж, Еховад үнэнчээр үйлчлэх түвшний хүн бараг байдаггүй. Та нар хэчнээн өрөвдөлтэй вэ!

Өнөөдөр, төгс болгуулах тухай яриа бол ердөө л нэг тал юм. Юу ч тохиолдсон бай хамаагүй та нар гэрчлэлийн энэ алхмыг зүй зохистой хийх ёстой. Хэрвээ та нараас сүмд Бурханд үйлчлэхийг хүссэн бол та нар яаж хийх байсан бэ? Хэрвээ чи тахилч биш бөгөөд ууган хүүгийн юм уу Бурханы хөвгүүдийн байр суурьгүй бол үнэнч байх чадвартай хэвээр байх уу? Чи хаанчлалыг түгээх ажилд бүх хүчин чармайлтаа зориулж бас л чадах уу? Чи Бурханы даалгасан ажлыг зүй зохистой хийх чадвартай хэвээр байх уу? Чиний амь хэр их өссөнийг үл харгалзан өнөөдрийн ажил чамайг бүрэн үнэмшүүлж, бүх үзлээ хойш тавихад хүргэнэ. Чамд амийг эрж хайхад хэрэгтэй зүйл байсан ч бай, үгүй ч бай, ерөнхийдөө Бурханы ажил чамайг бүрэн үнэмшүүлнэ. Зарим хүн: “Би Бурханд итгэдэг боловч амийг эрэлхийлэх гэж юу болохыг ойлгодоггүй” гэдэг. Зарим нь: “Би Бурханд итгэх итгэлдээ бүх будилчихлаа. Би төгс болгуулж чадахгүй гэдгээ мэднэ, иймээс гэсгээгдэхэд бэлэн байна” гэж хэлдэг. Гэсгээгдэж, устгагдахад бэлэн байгаа ийм хүмүүсээр ч гэсэн, өнөөдрийн ажлыг Бурхан хийж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх ёстой. Зарим хүн бас: “Би төгс болгуулъя гэж гуйдаггүй боловч өнөөдөр Бурханы бүх сургалтыг хүлээн авахад бэлэн байгаа бөгөөд хэвийн хүн чанарыг амьдран харуулж, хэв чанараа сайжруулж, Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагахад бэлэн байна …” гэдэг. Үүгээрээ тэд бас байлдан дагуулагдаж, гэрчлэл хийсэн ба тэр хүмүүсийн дотор Бурханы ажлын тухай зарим нэг мэдлэг байгааг энэ нь баталдаг. Ажлын энэ үе шат туйлын хурдан хийгдсэн бөгөөд ирээдүйд хилийн чанадад бүр ч илүү хурдан хийгдэнэ. Өнөөдөр хилийн

чанад дахь хүмүүс тэсэн ядан хүлээж, бүгд Хятад руу яарч байгаа—иймээс хэрвээ та нар бүрэн төгс болгуулж чадахгүй бол хилийн чанад дахь хүмүүст саад учруулна. Тэр үед та нар ямар байхаас үл хамааран, цаг нь ирэхэд Миний ажил эцэслэн дуусна! Та нар хэр сайн орсныг, эсвэл ямархуу вэ гэдгийг чинь Би анхаардаггүй; Миний бүх ажил та нараас болж саатахгүй. Би бүх хүн төрөлхтний ажлыг хийдэг ба Миний хувьд та нарт илүү их цаг зарцуулах хэрэггүй! Та нар хэтэрхий урам зориггүй, өөрсдийн ухамсар хэтэрхий дутмаг! Та нар төгс болгуулах үнэ цэнгүй—бараг ямар ч чадамжгүй! Ирээдүйд хүмүүс маш хааш яаш, салан задгай байсаар байж, өөрсдийн хэв чанарыг сайжруулах чадваргүй хэвээр үлдсэн ч гэсэн энэ нь бүхий л орчлон ертөнцийн ажлыг зогсоохгүй. Бурханы ажил дуусах цаг ирэхэд энэ нь дуусаж, хүмүүсийн таягдан хаягдах цаг ирэхэд тэд таягдан хаягдана. Мэдээж төгс болгуулах учиртай, төгс болгуулах үнэ цэнтэй хүмүүс ч бас төгс болгуулна—гэхдээ хэрвээ та нарт үнэхээр ямар ч найдвар байхгүй бол Бурханы ажил та нарыг хүлээхгүй! Эцэст нь чи байлдан дагуулагдах юм бол үүнийг ч бас гэрчлэл хийж байна хэмээн тооцно; Бурханы та нараас шаарддаг зүйлд хязгаар байдаг; хүний биеийн хэмжээ хэр өндөрт хүрч чадна, тэр нь түүнээс шаарддаг гэрчлэлийн өндөр юм. Ийм гэрчлэл хамгийн өндөр хязгаарт хүрч, цангинасан байна гэж хүний төсөөлдөгтэй энэ нь адилгүй—Хятад хүмүүс та нарт энэ нь биелэхийн аргагүй. Би энэ бүх хугацаанд та нартай харилцсан бөгөөд та нар өөрсдөө үүнийг харсан: Би та нарт эсэргүүцэхгүй бай, тэрслэхгүй бай, Миний нүднээс далдуур үймээн тарьдаг, саад болдог зүйл битгий хий гэж хэлсэн. Би эдгээр үгийг та нарын нүүрэн дээр олон удаа хэлсэн боловч хангалтгүй байсан—Намайг эргээд хармагц тэд өөрчлөгддөг, тэгэнгээ зарим нь огт гэмшихгүйгээр нууцаар Намайг эсэргүүцдэг. Намайг юу ч мэддэггүй гэж чи бодож байна уу? Надад төвөг удаад яах ч үгүй гэж чи бодож байна уу? Ар хударгаар минь Миний ажлыг нураахаар оролдож байгааг чинь мэдэхгүй гэж чи бодож байна уу? Чиний ялихгүй жаахан заль мэх ёс жудгийг чинь орлож чадна гэж бодож байна уу? Чи үргэлж хараажаар дуулгавартай байдаг боловч далдуур урвамтгай байдаг ба зүрх сэтгэлдээ хорон муу бодол нуудаг, чам шиг хүмүүст үхэл хүртэл хангалттай шийтгэл биш. Чам дахь Ариун Сүнсний багахан ажил Намайг гэсэн хүндлэлийг чинь орлож чадна гэж чи бодож байна уу? Тэнгэрийг дуудан хашхирснаар гэгээрэл олж авсан гэж бодож байна уу? Чи ичгүүр сонжуургүй юм! Чи бол маш үнэ цэнгүй! Чиний “сайн үйл хэрэг” Тэнгэрийг хөдөлгөсөн болохоор чамайг онцлон, уран цэцэн үгтэй төрөлхийн авъяас билгийг чамд хайрлаж, бусдыг хуурч, Намайг хуурах боломж олгосон гэж чи бодож байна уу? Чиний ухаалаг байдал хэчнээн дулимаг вэ! Чиний гэгээрэл хаанаас ирж байгааг чи мэдэх үү? Хэний хоолыг идэж өссөнөө чи мэдэхгүй гэж үү? Ямар мөс чанаргүй юм бэ! Та нарын дотроос зарим нь дөрөв таван жилийн харьцалтын дараа ч өөрчлөгдөөгүй; та нар эдгээр хэрэг явдлын талаар тодорхой мэднэ, мөн уг чанарынхаа талаар тодорхой мэдэж байх ёстой—иймээс нэг л өдөр хаягдах үедээ бүү дургүйц. Өөрсдийнхөө дээр, доор байдаг хүмүүсийн аль алийг

үйлчлэлээрээ хуурдаг зарим хүн ихээхэн харьцалт амссан; мөнгөнд шунахайгаасаа болоод зарим нь ихээхэн харьцалт туулсан; эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондох тодорхой зааг хязгаарыг баримтлаагүйн улмаас зарим нь ихээхэн харьцалт амссан; зарим нь залхуу агаад махан биеэ л анхаарч, чуулганд ирэх үедээ зарчмын дагуу үйлддэггүй учраас ихээхэн харьцалт туулсан; зарим нь хаа явсан газраа гэрчлэл хийж чаддаггүй, дур зоргоороо, болчимгүй авирлаж, бүр зориуд нүгэл үйлддэг учраас олон удаа сануулга авсан; зарим нь цуглааны үеэр ердөө үг, сургаал ярьж, бусдаас илүү дээр мэт аашилж, өчүүхэн төдий ч үнэн-бодит байдалгүй байж, ах эгч нарынхаа эсрэг хуйвалдаж, тэдэнтэй өрсөлдөж байдаг—тэд ихэвчлэн үүнийхээ улмаас илчлэгдсэн. Би эдгээр үгийг та нарт маш олон удаа хэлсэн ба өнөөдөр энэ тухай дахиж ярихгүй—хүссэнээ хийцгээ! Өөрсдийнхөө шийдвэрийг гарга! Олон хүн энэ харьцалтад ердөө ганц хоёр жил өртөөгүй, заримынх нь хувьд гурав, дөрвөн жил болсон, зарим нь үүнийг арваас дээш жил туулж байгаа ба итгэгчид болох үедээ харьцалтад өртсөн боловч өнөөг хүртэл тэдэнд өчүүхэн өөрчлөлт гарсан. Чи юу гэх вэ, чи гахайтай адил биш гэж үү? Бурхан чамд шударга бус хандаж байгаа юм гэж үү? Та нарыг тодорхой түвшинд хүрч чадахгүй л бол Бурханы ажил дуусахгүй гэж бүү бод. Хэрвээ та нар Бурханы шаардлагыг биелүүлж чадахгүй бол Тэр та нарыг хүлээсээр байна гэж үү? Би чамд ний нуугүй хэлье—тийм биш. Аливааг тийм өөдрөгөөр бүү хар! Өнөөдрийн ажилд цаг хугацааны хязгаар байгаа, Бурхан зүгээр л чамтай тоглож байгаа юм биш! Урьд нь, үйлчлэл үзүүлэгчдийн шалгалтыг туулах цаг ирэхэд, хэрвээ Бурханд өгөх гэрчлэлдээ бат зогсоё гэвэл тодорхой түвшинд байлдан дагуулагдах ёстой—дуртайяа, баяртайяа үйлчлэл үзүүлэгч байх ёстой ба Бурханыг өдөр бүр магтаж, өчүүхэн төдий ч хааш яаш, хайнга байж болохгүй гэж хүмүүс боддог байсан. Зөвхөн тэр үед л тэд үнэхээр үйлчлэл үзүүлэгч байж чадна гэж тэд бодсон, гэхдээ энэ нь үнэхээр тийм гэж үү? Тэр үед янз бүрийн хүмүүс илчлэгдсэн; тэд төрөл бүрийн ааш авир гаргасан. Зарим нь гомдоллож, зарим нь үзэл тарааж, зарим нь цуглаанд оролцохоо больж, зарим нь бүр чуулганы мөнгийг үрсэн. Ах эгч нар бие биеийнхээ эсрэг хуйвалдсан. Энэ нь үнэхээр асар их чөлөөлөлт байсан боловч үүнд нэг сайн зүйл байсан: Хэн ч ухраагүй. Тэр талаар хэлж болох хамгийн сайн зүйл энэ юм. Тэд үүнээс болж Сатаны өмнө гэрчлэл хийсэн бөгөөд дараа нь Бурханы ардуудын ялгамж чанарыг олж авч, өнөөдрийг хүртэл явсан. Бурханы ажил чиний төсөөлсөн шиг явагддаггүй. Цаг нь болоход та нар ямар байхаас үл хамааран ажил дуусна. Зарим хүн: “Ингэж авирласнаар Та хүмүүсийг авардаггүй, эсвэл хайрладаггүй—Та бол зөвт Бурхан биш” гэж хэлж магад. Би чамд ний нуугүй хэлье: Миний өнөөдрийн ажлын гол цөм нь чамайг байлдан дагуулж, чамаар гэрчлэл хийлгэх явдал юм. Чамайг аврах нь ердөө нэмэлт зүйл; аврагдах уу, үгүй юү гэдэг чинь чиний эрэл хайгуулаас хамаардаг ба Надтай холбоогүй. Гэсэн ч Би чамайг байлдан дагуулах ёстой; Намайг бурантагтай тэмээ шиг хөтлөхөөр үргэлж бүү оролд—өнөөдөр Би ажиллаж, чамайг авардаг, эсрэгээрээ биш!

Өнөөдөр та нарын ойлгосон зүйл түүхэн туршид төгс болгуулаагүй ямар ч хүнийхээс илүү өндөр. Шалгалтын талаарх мэдлэг чинь, эсвэл Бурханд итгэх итгэл чинь ямар ч итгэгчийнхээс өндөр. Та нарын ойлгодог зүйл орчны шалгалтыг туулахаасаа өмнө мэдэж авсан зүйл боловч жинхэнэ биеийн хэмжээ чинь тэдгээртэй огт нийцэлгүй байдаг. Та нарын мэддэг зүйл хэрэгжүүлдэг зүйлээс чинь илүү өндөр. Бурханд итгэдэг хүмүүс Бурханыг хайрлах ёстой ба ерөөлийн төлөө бус, харин Бурханы хүслийг хангалуун байлгахын төлөө л хичээх ёстой гэж та нар хэлдэг ч амьдралд чинь илэрхийлэгддэг зүйл үүнээс асар өөр бөгөөд ихээхэн өө сэвтэй. Ихэнх хүн амар амгалан байдлын төлөө болон бусад ашиг тусын төлөө Бурханд итгэдэг. Чиний ашиг тусын төлөө л биш бол чи Бурханд итгэдэггүй ба Бурханы нигүүлслийг хүлээн авч чадахгүй бол уруу царайлдаг. Энэ нь яаж чиний жинхэнэ биеийн хэмжээ байх юм бэ? Хүүхдүүд өвдөх, нөхөр эмнэлэгт хэвтэх, ургац муу ургах, гэр бүлийн гишүүдийн хавчлага гэх мэт гэр бүлийн зайлшгүй хэрэг явдлын тухайд гэвэл чи өдөр тутмын амьдралд ихэвчлэн тохиолддог эдгээр зүйлийг ч даван гарч чаддаггүй. Тийм зүйл тохиолдох үед чи самгардаж юу хийхээ мэдэхээ больдог—тэгээд ихэнхдээ Бурханы талаар гомдоллодог. Бурханы үг чамайг хуурч, Бурханы ажил чамаар доог тохуу хийсэн гэж чи Бурханд гомдоллодог. Та нарт тийм бодол байдаггүй гэж үү? Та нарын дунд тийм зүйлс тун ховорхон тохиолддог гэж чи бодож байна уу? Та нар тийм үйл явдлуудын дунд амьдарч өдөр бүрийг өнгөрөөдөг. Тэгээд Бурханд итгэх итгэлийнхээ амжилтыг болон Бурханы хүслийг хэрхэн хангалуун байлгах талаар өчүүхэн төдий ч бодож үздэггүй. Та нарын жинхэнэ биеийн хэмжээ хэтэрхий жаахан, бүр бяцхан дэгдээхэйнхээс ч илүү жаахан. Нөхрийн чинь бизнес алдагдалд ороход та нар Бурханы талаар гомдоллодог, Бурханы хамгаалалтгүй орчинд орсноо мэдэх үедээ мөн л Бурханы талаар гомдоллодог, дэгдээхэйнүүдийн чинь нэг нь үхэхэд, эсвэл малын хашаан дахь үхэр чинь өвдөхөд хүртэл гомдоллодог. Хүү чинь гэрлэх болсон ч танай гэр бүлд хангалттай мөнгө байхгүй байвал та нар гомдоллодог; гэртээ зочин байлгах үүрэг биелүүлэхийг хүсдэг боловч тэгж чадахгүй байх үедээ бас л гомдоллодог. Чиний гэдэс гомдлоор дүүрсэн байдгаас болоод чи заримдаа цуглаанд явдаггүй, эсвэл Бурханы үгийг идэж, уудаггүй бөгөөд чи асар урт хугацааны турш сөрөг болж магадгүй байдаг. Өнөөдөр чамд тохиолддог нэг ч зүйл чиний хэтийн ирээдүй, эсвэл хувь заяатай ямар нэгэн холбоогүй; хэрвээ чи Бурханд итгээгүй бол эдгээр зүйл мөн л тохиолдох байсан, гэсэн ч чи тэдгээрийн хариуцлагыг Бурхан руу чихэж, Бурхан чамайг таягдан хаясан гэж зүтгэсээр байдаг. Чи Бурханд чухамдаа хэр итгэдэг вэ, өөрийнхөө амийг үнэхээр өргөн барьсан уу? Хэрвээ та нар Иовтой адил шалгалт амссан бол өнөөдөр Бурханыг дагадаг та нарын дундаас нэг нь ч бат зогсож чадалгүй, бүгд унах байсан юм. Та нарыг Иовтой харьцуулбал яг л тэнгэр газар шиг асар их ялгаатай. Өнөөдөр, эд хөрөнгийн чинь хагасыг булаан авсан бол та нар Бурханы оршин тогтнолыг үгүйсгэж зүрхлэх байсан; хүү юм уу охиныг чинь авсан бол та нар гудамжаар гүйн

хараах байсан; амьдрал чинь мухардалд орсон бол Бурхантай тооцоо бодохоор оролдож, чамайг айлгахын тулд анх яагаад маш олон үг хэлснийг минь асуух байлаа. Тийм үед та нар юу ч хийж зүрхэлнэ. Та нар үнэхээр юу ч ойлгоогүй бөгөөд жинхэнэ биеийн хэмжээ огт байхгүйг чинь энэ нь харуулдаг. Тиймээс та нарыг шалгах шалгалтууд хэтэрхий их, учир нь та нар дэндүү ихийг ойлгодог боловч үнэхээр мэддэг зүйл чинь та нарын ухамсарласан зүйлийн мянганы нэгд ч хүрэхгүй. Ойлголт мэдлэг төдийхнөөр бүү зогс; та нар үнэндээ хэр ихийг хэрэгжүүлж чадахаа, мөн шаргуу ажлын чинь хэр их хөлс хүч Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт болж хувирсныг болон хэр олон хэрэгжүүлэлтдээ өөрсдийнхөө шийдвэрийг биелүүлснээ харсан чинь дээр. Чи өөрийнхөө биеийн хэмжээ болон хэрэгжүүлэлтийг нухацтай авч үзэх ёстой. Бурханд итгэх итгэлээрээ чи зүгээр л хэн нэгэнд хийсэн дүр үзүүлэхээр хичээх ёсгүй—эцэстээ үнэн болон амийг олж авч чадах уу, үгүй юү гэдэг чинь чиний өөрийн эрэл хайгуулаас хамаардаг.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 4

Өнөөдөр Миний ярьж байгаа амар амгалан, баяр хөөр нь чиний итгэж, ойлгодогтой адилгүй. Амар амгалан, баяр хөөр гэдэг нь бүхий л өдөржингөө аз жаргалтай байж, гэр бүлдээ өвчин эмгэг, золгүй явдалгүй, зүрх сэтгэлдээ өчүүхэн ч уй гашуу мэдрэлгүй, үргэлж сэтгэл хангалуун байж, амь чинь ямар хэмжээнд хүрснээс үл хамааран үгээр хэлэхийн аргагүй баяр хөөртэй байна гэсэн үг гэж чи боддог байсан. Дээр нь нэмээд цалин өсөж, хүү чинь их сургуульд дөнгөж элсэн орно. Эдгээр зүйлийг бодоод чи Бурханд залбирч, Бурханы нигүүлсэл маш агуу гэдгийг харж, баярласандаа марсайтлаа инээмсэглэн, Бурханд талархахаа больж чадахгүй. Тийм амар амгалан байдал, баяр хөөр нь Ариун Сүнсний дэргэд байхаас ирдэг жинхэнэ амар амгалан, баяр хөөр биш. Харин ч махан биеийн ханамжтай байдлаас үүдэн гардаг амар амгалан, баяр хөөр юм. Чи өнөөдөр ямар эрин үе болохыг ойлгох ёстой; энэ нь Нигүүлслийн эрин үе биш бөгөөд талхаар гэдсээ дүүргэхийг хичээдэг цаг үе байхаа больсон. Гэр бүлийн чинь бүх зүйл бүтэмжтэй байгаад чи хэт баярлаж байж болох ч чиний амь эцсийн амьсгалаа авч байгаа—тиймээс баяр хөөр чинь хэчнээн их байх нь хамаагүй, Ариун Сүнс чамтай хамт байдаггүй. Ариун Сүнстэй хамт байна гэдэг нь энгийн: хийх ёстой зүйлээ зүй зохистой хийж, хүний үүрэг, хариуцлагыг сайн биелүүлж, дутагдлаа нөхөхөд хэрэгтэй зүйлээр өөрийгөө зэвсэглэж чаддаг бай. Хэрвээ чи амийнхаа төлөө үргэлж хүнд ачаа үүрэн, үнэнийг ухамсарлаж, Бурханы одоогийн ажлыг ойлгосон учраас аз жаргалтай байдаг бол энэ нь үнэхээр Ариун Сүнсний дэргэд байгаа хэрэг юм. Эсвэл, хэрхэн туулахаа мэдэхгүй асуудалтай тулгарснаас болоод юм уу нөхөрлөж буй үнэнийг ойлгохгүйгээс болоод чи заримдаа санаа зовнилд автдаг бол Ариун Сүнс чамтай хамт байгааг энэ нь нотолдог. Эдгээр нь амийн туршлагын түгээмэл

байр байдал юм. Чи Ариун Сүнстэй хамт байх болон Ариун Сүнс байхгүй байхын хоорондох ялгааг ойлгох ёстой ба үүнийг хэтэрхий энгийнээр авч үзэх ёсгүй.

Урьд нь, Ариун Сүнсний дэргэд байх болон Ариун Сүнсний ажилтай байх нь ялгаатай гэж хэлдэг байсан. Ариун Сүнсний дэргэд байх хэвийн байр байдал нь хэвийн бодол, хэвийн эрүүл ухаан, хэвийн хүн чанартай байхаар илэрхийлэгддэг. Хүний жудаг урьдынхаараа л үлдэх боловч дотроо амар амгалан болж, гаднаа ариун хүний төрх байдалтай байх болно. Ариун Сүнс тэдэнтэй хамт байх үед тэд ийм байна. Ариун Сүнс хамт байх үед хүн хэвийн бодолтой байдаг. Өлсөх үедээ тэд идэхийг хүсэж, цангасан үедээ тэд ус уухыг хүсдэг… Хэвийн хүн чанарын ийм илрэлүүд нь Ариун Сүнсний гэгээрэл биш; тэдгээр нь Ариун Сүнстэй хамт байгаа хүмүүсийн хэвийн бодол, хэвийн байр байдал юм. Зарим хүн, Ариун Сүнстэй хамт байгаа хүмүүс өлсөхийг мэддэггүй, ядрахыг мэддэггүй, гэр бүлийнхнээ огт боддоггүй мэт санагддаг ба махан биеэс өөрсдийгөө бараг бүрмөсөн салгасан байдаг гэж эндүүрэн итгэдэг. Үнэндээ Ариун Сүнс хүмүүстэй хамт байх тусам, тэд төдий чинээ хэвийн байдаг. Тэд Бурханы төлөө зовж, аливааг орхиж, өөрсдийгөө зарлагадаж, Бурханд үнэнч байхыг мэддэг; түүнчлэн хоол унд, хувцас хунарын талаар боддог. Өөрөөр хэлбэл, тэд хүмүүст байх учиртай хэвийн хүн чанарын юуг ч гээгээгүй байдаг ба харин ч нэн эрүүл ухаантай байдаг. Заримдаа тэд Бурханы үгийг уншиж, Бурханы ажлыг тунгаан боддог; тэдний зүрх сэтгэлд итгэл байдаг бөгөөд үнэнийг эрэлхийлэхэд бэлэн байдаг. Ариун Сүнсний ажил мэдээж энэ суурин дээр үндэслэдэг. Хэрвээ хүмүүст хэвийн сэтгэхүй байхгүй бол тэдэнд эрүүл ухаан байхгүй байх ба энэ нь хэвийн байдал биш юм. Хүмүүс хэвийн сэтгэхүйтэй, Ариун Сүнстэй хамт байх үедээ хэвийн хүний эрүүл ухааныг гарцаагүй эзэмшдэг бөгөөд улмаар хэвийн байр байдалтай байдаг. Бурханы ажлыг туулах үед хаяа л Ариун Сүнсний ажилтай байдаг байхад байнга шахуу Ариун Сүнстэй хамт байдаг. Хүмүүсийн эрүүл ухаан болон сэтгэхүй хэвийн байгаа цагт, мөн байр байдал нь хэвийн байгаа цагт Ариун Сүнс гарцаагүй хамт байдаг. Хүмүүсийн эрүүл ухаан болон сэтгэхүй хэвийн биш байх үед хүн чанар нь хэвийн биш байдаг. Хэрвээ энэ мөчид Ариун Сүнсний ажил чамд байгаа бол Ариун Сүнс ч бас гарцаагүй чамтай хамт байх болно. Гэхдээ Ариун Сүнс чамтай хамт байдаг бол Ариун Сүнс заавал чиний дотор ажиллаж байх албагүй, учир нь Ариун Сүнс онцгой цагт ажилладаг билээ. Ариун Сүнстэй хамт байх нь зөвхөн хүмүүсийн хэвийн оршин тогтнолыг л хадгалж чадах боловч Ариун Сүнс тодорхой цаг хугацаанд л ажилладаг. Жишээлбэл, хэрвээ чи удирдагч юм уу ажилчин бол чуулганыг усалж, тэжээлээр хангах үед чинь бусдад сургамжтай, мөн ах эгч нарын чинь зарим бодитой асуудлыг шийдвэрлэж чадах зарим үгээр Ариун Сүнс чамайг гэгээрүүлнэ—ийм үед Ариун Сүнс ажиллаж байгаа. Заримдаа, Бурханы үгийг идэж, ууж байх үед чинь ялангуяа чиний туршлагатай холбоотой зарим нэг үгээр Ариун Сүнс чамайг гэгээрүүлэн, өөрийнхөө байр байдлын талаар илүү их мэдэх боломж олгодог; энэ нь ч бас Ариун Сүнсний ажил юм. Заримдаа, Намайг ярихад та нар сонсож,

өөрсдийнхөө байр байдлыг Миний үгтэй харьцуулан хэмжиж чаддаг бөгөөд заримдаа та нарын сэтгэл хөдөлж, эсвэл зоригждог; энэ бүхэн нь Ариун Сүнсний ажил юм. Ариун Сүнс цаг ямагт өөрсөд дээр нь ажиллаж байгаа гэж зарим хүн хэлдэг. Тэгэх боломжгүй. Ариун Сүнс үргэлж өөрсөдтэй нь хамт байдаг гэж хэлэх юм бол бодитой байна. Өөрсдийнх нь сэтгэхүй, эрүүл ухаан нь цаг үргэлж хэвийн байдаг гэж хэлэх юм бол тэр нь ч бас бодитой байж, Ариун Сүнс тэдэнтэй хамт байгааг харуулах байсан. Хэрвээ тэд, Ариун Сүнс үргэлж дотор нь ажиллаж, хором бүрд өөрсдийг нь Бурхан гэгээрүүлж, Ариун Сүнс сэтгэлийг нь хөдөлгөдөг, тэгээд тэд цаг ямагт шинэ мэдлэг олж авдаг гэж хэлэх юм бол энэ нь яавч хэвийн биш! Энэ нь тэр чигтээ ер бусын хэрэг юм! Тийм хүмүүс бол муу ёрын сүнс гэдэг нь өчүүхэн ч эргэлзээгүй! Бурханы Сүнс махбодод ирэх үедээ ч гэсэн Түүнд хооллох ёстой, амрах ёстой цаг гэж бий—хүмүүсийн тухайд бол ярихын ч хэрэггүй. Муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн хүмүүст махан биеийн сул тал байдаггүй мэт санагддаг. Тэд бүх зүйлийг хаяж, орхиж чаддаг, сэтгэл хөдлөлөөс ангид, тарчлааныг тэсвэрлэх чадвартай бөгөөд махан биеийг даван гарсан мэт өчүүхэн ч ядардаггүй. Ингэх нь туйлын ер бусын биш үү? Муу ёрын сүнсний ажил ер бусын байдаг—нэг ч хүн ийм зүйлд хүрч чадахгүй! Ялган таних чадваргүй хүмүүс тийм хүмүүсийг харахаараа атаархаж, тэд бол Бурханд итгэхдээ маш эрч хүчтэй, асар их итгэлтэй, сул дорой байдлын өчүүхэн ч шинж тэмдгийг харуулдаггүй гэж хэлдэг! Үнэндээ эдгээр нь муу ёрын сүнсний ажлын илрэл юм. Учир нь, хэвийн хүмүүст хүний сул тал зайлшгүй байдаг; энэ бол Ариун Сүнстэй хамт байгаа хүмүүсийн хэвийн байр байдал юм.

Гэрчлэлдээ бат зогсоно гэдэг нь юу гэсэн үг вэ? Зарим хүн, одоогийнх шигээ зүгээр л дагадаг ба амийг олж авч чадах эсэх талаар санаа зовдоггүй; амийг эрэлхийлдэггүй гэж хэлдэг боловч бас ухарч буцдаггүй. Тэд ажлын энэ үе шатыг л Бурхан гүйцэтгэж байгаа гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ нь гэрчлэлдээ бүтэлгүйтэж байгаа хэрэг биш үү? Тийм хүмүүс байлдан дагуулагдах тухай гэрчлэл ч хийдэггүй. Байлдан дагуулагдсан хүмүүс бусад бүх зүйлийг үл хамааран дагадаг ба амийг эрэлхийлж чаддаг. Тэд бодитой Бурханд итгээд зогсохгүй, мөн Бурханы бүх зохицуулалтыг дагахаа мэддэг. Тэд бол гэрчлэл хийдэг хүмүүс юм. Гэрчлэл хийдэггүй хүмүүс хэзээ ч амийг эрэлхийлээгүй ба учраа олохгүй дагасаар л байдаг. Чи дагадаг байж болох боловч энэ нь байлдан дагуулагдсан гэсэн үг биш, учир нь чи өнөөдрийн Бурханы ажлын талаар ямар ч ойлголтгүй байдаг. Байлдан дагуулагдахын тулд тодорхой болзлуудыг хангах ёстой. Дагадаг бүх хүн байлдан дагуулагдсан биш, учир нь зүрх сэтгэлдээ чи өнөөдрийн Бурханыг яагаад дагах ёстойгоо огт ойлгодоггүй, мөн яаж өдий хүрснээ, өнөөдрийг хүртэл хэн чамайг дэмжсэнийг ч мэддэггүй. Зарим хүн Бурханд итгэх итгэлээ хэрэгжүүлэхдээ үргэлж мунгинаж, будилдаг; тиймээс дагах гэдэг нь гэрчлэлтэй гэсэн үг байх албагүй. Жинхэнэ гэрчлэл гэж яг юу юм бэ? Энд ярьж байгаа гэрчлэл хоёр хэсэгтэй: Нэг нь байлдан дагуулагдсаны гэрчлэл, нөгөө нь төгс болгуулсны гэрчлэл (энэ нь мэдээж,

хожмын асар их шалгалт, гай зовлонгийн дараах гэрчлэл байна). Өөрөөр хэлбэл, хэрвээ чи гай зовлон, шалгалтуудын үеэр бат зогсож чаддаг бол гэрчлэлийн хоёр дахь алхмыг хийчихсэн байх болно. Өнөөдрийн шийдвэрлэх чухал зүйл бол гэрчлэлийн эхний алхам буюу гэсгээлт, шүүлтийн шалгалт болгонд бат зогсож чаддаг байх явдал юм. Энэ нь байлдан дагуулагдах тухай гэрчлэл билээ. Учир нь одоо үе бол байлдан дагуулалтын цаг үе. (Одоо үе бол газар дээрх Бурханы ажлын цаг үе; бие махбодтой болсон Бурханы газар дээрх үндсэн ажил бол газар дээр Өөрийг нь дагадаг энэ бүлэг хүмүүсийг шүүлт, гэсгээлтээр дамжуулан байлдан дагуулах явдал юм гэдгийг чи мэдэх ёстой.) Чи байлдан дагуулагдах талаар гэрчлэл хийх чадвартай байх эсэх нь эцсийг нь хүртэл дагаж чадах эсэхээс чинь хамааraад зогсохгүй үүнээс ч чухал нь, Бурханы ажлын алхам бүрийг туулангаа Бурханы гэсгээлт, шүүлтийн талаар үнэхээр ойлгож чадах эсэхээс, мөн энэ бүх ажлыг үнэхээр ухамсарладаг эсэхээс чинь хамаардаг. Бүр эцсийг нь хүртэл дагах төдийхнөөр арай ядан ард нь гарч чадахгүй. Чи гэсгээлт, шүүлтийн тохиолдол болгонд дуртайяа буулт хийж чаддаг, туулж байгаа ажлынхаа алхам бүрийг үнэхээр ойлгох чадвартай байх ёстой бөгөөд Бурханы зан чанарын талаарх мэдлэгт хүрч, дуулгавартай байж чаддаг байх ёстой. Энэ нь та нараас шаарддаг байлдан дагуулагдсан тухай эцсийн гэрчлэл юм. Байлдан дагуулагдах тухай гэрчлэл нь үндсэндээ бие махбодтой болсон Бурханы талаарх мэдлэгийг чинь хэлдэг. Хамгийн гол нь, гэрчлэлийн энэ алхам нь бие махбодтой болсон Бурханы төлөө байдаг. Чи дэлхий ертөнцийн хүмүүсийн өмнө, эсвэл эрх мэдэлтэй хүмүүсийн өмнө юу хийж, хэлдэг чинь хамаагүй; хамгийн чухал нь чи Бурханы амнаас гарсан бүх үгийг болон Түүний бүх ажлыг дуулгавартай дагаж чаддаг эсэх юм. Тиймээс гэрчлэлийн энэ алхам нь Сатан болон Бурханы бүх дайсан руу буюу Бурхан хоёр дахь удаагаа махбод болж, бүр илүү агуу ажлыг хийхээр ирнэ гэдэгт итгэдэггүй, цаашлаад Бурхан махбодод эргэн ирсэн тухай баримтад итгэдэггүй чөтгөрүүд болон өстөн дайснууд рүү чиглэдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь бүх антихрист рүү—бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй бүх дайсан руу чиглэдэг.

Бурханыг бодож, Бурханыг хүсэн тэмүүлэх нь Бурханаар байлдан дагуулагдсан гэдгийг чинь нотолдоггүй; энэ нь, Тэр бол махбод болсон Үг гэдэгт итгэдэг эсэхээс чинь, Үг махбод болсон гэдэгт итгэдэг эсэхээс чинь, Сүнс Үг болсон ба Үг нь махбодоор илэрсэн гэдэгт итгэдэг эсэхээс чинь хамаардаг. Энэ нь гол гэрчлэл мөн. Хэрхэн дагадаг чинь, эсвэл өөрийгөө хэрхэн зарлагаддаг чинь хамаагүй; гол чухал зүйл бол, Үг махбод болсон ба үнэний Сүнс махбодод биеллээ олсон—бүх үнэн, амь, зам махбодод ирж, Бурханы Сүнс үнэхээр газар дээр хүрэлцэн ирж, махбодод ирсэн гэдгийг чи энэ хэвийн хүн чанараас олж илрүүлж чадах уу, үгүй юу гэдэг юм. Хэдийгээр өнгөцхөндөө энэ нь Ариун Сүнснээс үр тогтохоос өөр харагддаг ч энэ ажлаас чи, Сүнс аль хэдийн махбодод биеллээ олж, цаашлаад Үг махбод болж, Үг нь махбодоор илэрсэн гэдгийг илүү тодорхой харж чадна. Тэгээд дараах үгийн жинхэнэ утгыг ойлгож чадна: “Анх Үг байв, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь

Бурхан байлаа.” Түүнчлэн өнөөдрийн Үг бол Бурхан гэдгийг чи ойлгож, Үг махбод болсныг харах ёстой. Энэ бол чиний хийж чадах хамгийн сайн гэрчлэл билээ. Чи махбод болсон Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй гэдгийг энэ нь нотолдог—чи Түүнийг мэдэж чадахаар үл барам, өнөөдрийн алхдаг зам чинь амийн зам, үнэний зам мөн гэдгийг ч бас мэддэг. Есүсийн гүйцэтгэсэн ажлын үе шат “Үг Бурхантай хамт байсан” гэдгийн мөн чанарыг л биелүүлсэн: Бурханы үнэн Бурхантай хамт байж, Бурханы Сүнс махбодтой хамт байсан ба тэрхүү махбодоос салшгүй байв. Өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы бие Бурханы Сүнстэй хамт байсан нь бие махбодтой болсон Есүс бол эхний удаа бие махбодтой болсон Бурхан мөн гэдгийн бүр ч том нотолгоо юм. Ажлын энэ үе шат нь “Үг махбод болсон” гэдгийн дотоод утга учрыг яг таг биелүүлж, “Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан” гэдгийг илүү гүн утга учиртай болгосон бөгөөд “Анх Үг байсан” хэмээх үгэнд бат итгэх боломжийг чамд олгодог. Өөрөөр хэлбэл, бүтээлийн цаг үед Бурханд үг байсан, Түүний үг Түүнтэй хамт, Түүнээс салшгүй байсан ба эцсийн эрин үед Тэрээр Өөрийн үгийн хүч чадал, эрх мэдлийг бүр илүү тодорхой болгон, хүнд Өөрийн бүх арга замыг харуулж—бүх үгээ сонсгодог. Энэ нь эцсийн эрин үеийн ажил юм. Чи эдгээр зүйлийг нэгд нэггүй ойлгож авах ёстой. Энэ нь бие махбодыг мэдэх асуудал биш, харин махбод болон Үгийг ойлгох тухай юм. Энэ нь чиний хийх ёстой гэрчлэл, хүн бүрийн мэдэх ёстой зүйл билээ. Энэ бол хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханы ажил—Бурхан махбод болдог сүүлчийн удаа учраас бие махбод болохын ач холбогдлыг бүрэн дүүрэн гүйцэлдүүлж, махбод дахь Бурханы ажлыг бүгдийг нь гүйцэд хэрэгжүүлэн, гаргаж, махбод дахь Бурханы оршихуйн эринийг төгсгөл болгодог. Тиймээс чи бие махбодтой болохын утга учрыг мэдэх ёстой. Хэр их ийш тийш гүйсэн чинь, эсвэл гадаад талын бусад хэрэг явдлыг хэр сайн гүйцэтгэдэг чинь хамаагүй; бие махбодтой болсон Бурханы өмнө үнэхээр захирагдаж, бүхий л оршихуйгаа Бурханд зориулж, Түүний амнаас гардаг бүх үгийг дуулгавартай дагаж чадах эсэх чинь л чухал. Энэ бол чиний хийх ёстой, баримтлах ёстой зүйл билээ.

Гэрчлэлийн эцсийн алхам бол төгс болгуулж чадах эсэхийн чинь тухай гэрчлэл юм—өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы амаар хэлэгдсэн бүх үгийг ойлгоод чи Бурханы тухай мэдлэгтэй болж, Түүний талаар тодорхой мэддэг болж, Бурханы амнаас гардаг бүх үгийг амьдран харуулж, чамаас шаарддаг Петрийн хэв маяг болон Иовын итгэл гэх Бурханы болзлыг биелүүлж, тэгснээр үхэх хүртлээ дуулгавартай байж, өөрийгөө тэр чигт нь Түүнд өгч, эцэст нь стандартад нийцэх хүний дүр төрхөд хүрдэг ба энэ нь Бурханы шүүлт, гэсгээлтийг туулсны дараа байлдан дагуулагдаж, төгс болгуулсан хүний дүр төрх гэсэн үг юм. Энэ нь эцсийн гэрчлэл—эцэстээ төгс болгуулсан хүний хийх учиртай гэрчлэл билээ. Эдгээр нь чиний хийх ёстой гэрчлэлийн хоёр алхам бөгөөд тэдгээр нь харилцан уялдаатай, аль аль нь зайлшгүй хэрэгтэй. Гэхдээ чиний мэдэх ёстой нэг зүйл бий: Өнөөдөр чамаас Миний шаарддаг гэрчлэл дэлхий ертөнцийн хүмүүс рүү чиглэдэггүй, ямар

нэгэн хувь хүн рүү ч чиглэдэггүй, харин чамаас Миний шаарддаг зүйлд чиглэдэг. Энэ нь, Намайг хангалуун байлгаж чаддаг эсэхээр чинь болон та бүхэнд тавих Миний шаардлагын стандартад бүрэн нийцэж чадах эсэхээр чинь хэмжигддэг. Энэ бол та нарын ойлгох ёстой зүйл юм.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 5

Нигүүлслийн эрин үед Есүс зарим нэг үгийг айлдаж, ажлын нэг үе шатыг гүйцэтгэсэн. Тэдгээрт бүгдэд нь орчин нөхцөл байсан бөгөөд тухайн үеийн хүмүүсийн байр байдалд тохиромжтой байв; Есүс тухайн үеийн орчин нөхцөлд тохируулан үг хэлж, ажилласан. Тэр бас зарим нэг зөгнөл хэлсэн билээ. Үнэний Сүнс эцсийн өдрүүдэд ирж, ажлын нэг үе шатыг гүйцэтгэнэ гэж Тэрээр зөгнөсөн юм. Өөрөөр хэлбэл, Тэрээр тухайн эрин үед Өөрийнхөө хийх ажлаас өөр юуг ч ойлгоогүй; өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы авчирдаг ажил хязгаарлагдмал юм. Тиймээс, Тэр зөвхөн Өөрийнхөө байгаа эрин үеийн ажлыг л хийдэг бөгөөд Өөртэй нь холбоогүй бусад ажлыг хийдэггүй. Тухайн үед Есүс мэдрэмж юм уу үзэгдлүүдийн дагуу ажиллаагүй, харин цаг хугацаа, орчин нөхцөлд тохируулан ажилласан. Хэн ч Түүнийг удирдан, чиглүүлээгүй. Түүний ажил тэр чигтээ Өөрийнх нь оршихуй байсан—энэ нь бие махбодтой болсон Бурханы Сүнсний гүйцэтгэх учиртай ажил байсан ба бие махбодтой болсон Бурханы эхлүүлсэн бүхий л ажил байв. Есүс Өөрийнхөө харж, сонссон зүйлийн дагуу л ажилласан. Өөрөөр хэлбэл, Сүнс шууд ажилласан; элчүүд Түүнд харагдаж, Түүнд зүүд зүүдлүүлж, эсвэл ямар нэгэн агуу гэрэл Түүн дээр тусаж, Түүнд харуулах хэрэггүй байлаа. Тэр чөлөөтэйгээр, хязгаарлалтгүйгээр ажилласны учир нь Түүний ажил мэдрэмжид үндэслээгүй байсан юм. Өөрөөр хэлбэл, ажиллах үедээ Тэрээр тэмтчиж, таамаглаж байгаагүй, харин аливааг амархан хийж, Өөрийнхөө санааны дагуу болон нүдээр харсан зүйлийнхээ дагуу ажиллаж, үг хэлж, Өөрийг нь дагаж байсан шавь нэг бүрээ цаг тухайд нь хангаж байв. Энэ нь Бурханы ажил болон хүмүүсийн ажлын хоорондох ялгаа юм: Хүмүүс ажиллах үедээ эрж хайж, тэмтчин явж, илүү гүн оролтод хүрэхийн тулд бусдын тавьсан суурин дээр үндэслэн үргэлж дуурайж, цэгнэн нягталж байдаг. Бурханы ажил бол Тэр юу болохын хангалт бөгөөд Тэрээр хийх учиртай ажлаа хийдэг. Тэрээр хэн нэгэн хүний ажлаас гарсан мэдлэгийг ашиглан чуулганыг хангадаггүй. Харин ч, хүмүүсийн байр байдалд үндэслэн өнөөгийн ажлыг хийдэг. Тиймээс, ийм маягаар ажиллах нь хүмүүсийн хийдэг ажлаас хэдэн мянга дахин илүү эрх чөлөөтэй. Хүмүүсийн хувьд, Бурхан үүргээ мөрддөггүй, хүссэнээрээ ажилладаг мэт харагдаж болох боловч Түүний хийдэг бүх ажил шинэ байдаг. Гэхдээ, бие махбодтой болсон Бурханы ажил хэзээ ч мэдрэмжид үндэслэдэггүй гэдгийг чи мэдэх ёстой. Тухайн үед Есүсийг цовдлогдох ажлаа гүйцэлдүүлсний дараа, Есүсийг дагаж байсан шавь нар нь

туршлагаараа тодорхой хэмжээнд хүрмэгцээ, Бурханы өдөр ирж байгаа бөгөөд Эзэнтэй удахгүй уулзана гэдгээ мэдэрсэн. Тэр нь тэдэнд байсан мэдрэмж бөгөөд тэдний хувьд энэ мэдрэмж хамгийн чухал байжээ. Гэвч үнэндээ хүмүүсийн доторх мэдрэмж найдвартай биш. Тэдэнд, магадгүй замынхаа төгсгөлд бараг хүрэх гэж байна, эсвэл хийсэн, зовсон бүхнийг нь Бурхан урьдчилан тогтоожээ гэж санагдсан юм. Паул ч бас, өөрийн замыг дуусгаж, сайн тэмцлээр тэмцсэн бөгөөд зөвт байдлын титэм өөрт нь зориулагдан зэхэгдсэн хэмээн хэлсэн. Түүнд тэгж санагдаж байсан ба тэр үүнийгээ захидалдаа бичин, чуулганууд руу илгээжээ. Тийм үйлдлүүд нь чуулгануудын төлөө түүний үүрсэн ачаанаас гарсан тул Ариун Сүнс үүнийг үл тоосон юм. Тэдгээр үгийг хэлэх үед Паулд түгшсэн мэдрэмж байгаагүй, мөн ямар ч зэмлэлийг мэдрээгүй тул ийм зүйлс нь маш хэвийн, нэлээд зөв бөгөөд Ариун Сүнснээс ирсэн гэж тэр итгэжээ. Гэхдээ өнөөдөр харвал, энэ нь огтхон ч Ариун Сүнснээс ирээгүй. Харин хүний төөрөгдөл төдий байв. Хүмүүсийн дотор олон төөрөгдөл байдаг ба тийм зүйл тохиолдох үед Бурхан анхаарал тавьдаггүй, эсвэл ямар нэгэн үзэл бодол илэрхийлдэггүй. Ариун Сүнсний ажлын дийлэнх нь хүмүүсийн мэдрэмжээр дамжуулан хийгддэггүй—Бурхан махбод болохын өмнөх хүнд бэрх, хар бараан үе юм уу ямар ч элч, ажилчид байхгүй цаг үеэс бусад үед Ариун Сүнс хүмүүсийн мэдрэмж дотор ажилладаггүй. Тэрхүү үе шатанд Ариун Сүнсний ажил нь хүмүүст зарим нэг онцгой мэдрэмжүүдийг өгдөг. Жишээлбэл: Хүмүүс Бурханы үгийн удирдамжгүй байх үедээ залбирахаараа үгээр хэлэхийн аргагүй аз жаргалыг мэдэрдэг; тэд зүрх сэтгэлдээ таашаал мэдэрч, санаа амар, тайван байдаг. Үгийн удирдамжтай болмогц хүмүүсийн сүнс цэлмэж, үйлдэлдээ хэрэгжүүлэлтийн замтай болдог ба мэдээж бас амар тайван, санаа амар байх мэдрэмж тэдэнд төрдөг. Аюултай тулгарах үедээ, эсвэл тодорхой нэг зүйл хийхийг нь Бурхан болиулах үед хүмүүс зүрх сэтгэлдээ түгшиж, тавгүйтдэг. Эдгээр нь тэр чигтээ, хүнд Ариун Сүнсний өгдөг мэдрэмж юм. Гэхдээ дайсагнасан орчин нь айдсын уур амьсгал төрүүлж, хүмүүсийг ер бусын их түгшүүртэй, хулчгар болгодог бол тэр нь хүн чанарын хэвийн илэрхийлэл бөгөөд Ариун Сүнсний ажилтай хамаагүй байдаг.

Хүмүүс үргэлж өөрсдийнхөө мэдрэмж дунд амьдардаг бөгөөд олон жилийн туршид ийм байсаар ирсэн. Зүрх сэтгэлдээ амар тайван байх үедээ тэд (өөрсдийнхөө бэлэн байдлыг амар тайвны мэдрэмж хэмээн итгэж) үйлддэг бөгөөд зүрх сэтгэл дотроо тайван биш байх үедээ (өөрсдийнхөө халшрал, эсвэл дургүйцлийг түгшүүртэй мэдрэмж хэмээн итгэж) үйлдэл хийдэггүй. Хэрвээ юмс төвөггүй явагдвал энэ нь Бурханы хүсэл гэж тэд боддог. (Үнэндээ энэ нь тун төвөггүй явагдах учиртай зүйл буюу аливаа зүйлийн байгалийн хууль юм.) Юмс төвөггүй явагдахгүй байх үед, энэ нь Бурханы хүсэл биш гэж тэд боддог. Төвөггүй явагддаггүй зүйлтэй тулгарах үедээ тэд зогсдог. Тийм мэдрэмжүүд нь үнэн зөв биш бөгөөд тэдгээрийн дагуу үйлдэх нь олон саад тотгор учруулна. Жишээ нь, үнэнийг хэрэгжүүлэхэд бэрхшээл байх нь гарцаагүй бөгөөд Бурханы хүслийг биелүүлэхэд

бүр ч их бэрхшээл байна. Олон эерэг зүйлийг биелүүлэхэд хэцүү байх болно. “Сайныг хийхэд саад бэрхшээл тулгардаг” гэж хэлдэгтэй яг адилхан. Хүмүүсийн бодит амьдралд хэтэрхий олон мэдрэмж байдаг ба тэднийг олон зүйл дээр байнга будилуулж, тээнэгэлзүүлж орхидог. Үнэнийг ойлгож чадахгүй л бол хүмүүсийн хувьд юу ч тодорхой биш байдаг. Гэвч ерөнхийдөө, тэднийг өөрсдийнхөө мэдрэмжийн дагуу үйлдэх юм уу ярих үед, энэ нь үндсэн зарчмыг зөрчдөг зүйл биш л бол Ариун Сүнс огтхон ч хариу үйлдэл үзүүлдэггүй. Энэ нь Паулын мэдэрсэн “зөвт байдлын титэм”-тэй адилхан: Олон жилийн турш, түүний мэдрэмж буруу байсан гэдэгт хэн ч итгээгүй, мөн өөрийнх нь мэдрэмж андуу ташаа байсан гэдгийг Паул өөрөө ч огт мэдрээгүй. Хүмүүсийн мэдрэмж хаанаас гардаг вэ? Тэдгээр нь мэдээж тэдний уураг тархинаас гардаг хариу үйлдэл юм. Ялгаатай орчин, өөр өөр хэрэг явдлын дагуу өөр өөр мэдрэмж төрдөг. Ихэнх тохиолдолд, хүмүүс хүний логикоор дүгнэлт хийж, цогц томьёоллыг гаргадаг ба энэ нь олон мэдрэмж төрүүлдэг. Хүмүүс өөрийн мэдэлгүй логик дүгнэлтдээ орж, ийм маягаар эдгээр мэдрэмж нь амьдралдаа хүмүүсийн түшиглэдэг зүйл болдог; тэдгээр нь Паулын “зөвт байдлын титэм” шиг, эсвэл Витнес Лигийн “агаарт Эзэнтэй уулзах” шиг, тэдний амьдрал дахь сүнслэг багана болдог. Хүний энэ мэдрэмжүүдэд оролцох арга Бурханд бараг байхгүй ба өөрсдийнхөөр нь өрнүүлэх хэрэгтэй болдог. Өнөөдөр Би чамтай үнэний янз бүрийн талын тухай илэн далангүй ярилаа. Хэрвээ чи өөрийнхөө мэдрэмжээр үргэлжлүүлэн явсаар байвал тодорхойгүй байдал дунд амьдарсаар байхгүй гэж үү? Илт чиний төлөө зориулагдсан үгийг чи хүлээн зөвшөөрөлгүй, үргэлж өөрийнхөө мэдрэмжид найддаг. Үүгээрээ чи зааныг тэмтэрч буй сохор хүнтэй адил биш гэж үү? Тэгвэл чи эцэст нь юу олж авах юм бэ?

Өнөөдөр бие махбодтой болсон Бурханы хийсэн бүхэн бодитой. Энэ нь чиний мэдэрч, эсвэл төсөөлж чадах зүйл биш, тэр ч бүү хэл, дүгнэж чадах зүйл чинь биш—харин бодит баримтууд тохиолдох үед л чиний ойлгож чадах зүйл юм. Заримдаа тэдгээр нь тохиолдох үед ч чи тодорхой харж чадахгүй хэвээр байдаг ба Бурхан биечлэн ажиллаж, тохиолдож байгаа зүйлсийн бодит баримтыг асар их тодорхой болгох үед л хүмүүс ойлгоно. Тухайн үед Есүсийг дагаж байсан шавь нарын дунд олон төөрөгдөл байв. Тэд, Бурханы өдөр ирэх гэж байгаа ба өөрсдөө удалгүй Есүсийн төлөө үхэж, Эзэн Есүстэй уулзаж чадна гэж итгэж байлаа. Петр энэ мэдрэмжээс болоод бүтэн долоон жил хүлээсэн—гэсэн ч энэ нь ирээгүй юм. Өөрсдийнх нь амь төлөвшсөн гэж тэдэнд санагджээ; доторх мэдрэмж нь өсөн нэмэгдэж, эдгээр мэдрэмж улам хурц болсон боловч тэд олон бүтэлгүйтлийг туулаад, амжилтад хүрч чадаагүй юм. Юу болоод байгааг тэд өөрсдөө мэдэхгүй байлаа. Үнэхээр Ариун Сүнснээс ирсэн зүйл биелэхгүй байж болох уу? Хүмүүсийн мэдрэмж найдвартай биш. Хүмүүст өөрсдийн гэсэн бодол, санаа байдаг учраас тухайн үеийн орчин нөхцөл болон байр байдалд үндэслэн тэд баялаг холбоо сүлбээ бий болгодог. Ялангуяа эрүүл бодолтой хүмүүст ямар нэгэн зүйл тохиолдох үед тэд хэт их баярладаг бөгөөд баялаг холбоо сүлбээ бий болгохгүй байж

чаддаггүй. Энэ нь ялангуяа өргөн мэдлэг, онолтой “мэргэжилтнүүдэд” хамаардаг ба дэлхий ертөнцтэй олон жил харьцсаны дараа холбоо сүлбээ нь бүр ч элбэг арвин болдог; нэг л мэдэхэд тэдгээр холбоо сүлбээ нь зүрх сэтгэлийг нь эзэмдэж, туйлын хүчтэй мэдрэмж нь болдог бөгөөд үүнд тэдний сэтгэл ханадаг. Хүмүүс ямар нэгэн зүйл хийхийг хүсэх үед дотор нь мэдрэмж, төсөөллүүд гарч ирэх бөгөөд хүмүүс тэдгээрийг зөв гэж бодно. Дараа нь тэдгээр нь биелээгүйг харах үедээ хүмүүс юу нь буруудсаныг олж мэдэж чаддаггүй. Магадгүй тэд Бурхан төлөвлөгөөгөө өөрчилчихжээ гэж итгэдэг.

Бүх хүнд мэдрэмж байдаг нь зайлшгүй. Хуулийн эрин үед олон хүнд бас тодорхой мэдрэмж байсан боловч тэдний мэдрэмж дэх алдаа мадаг нь өнөөгийн хүмүүсийнхээс бага байв. Яагаад гэвэл, урьд нь хүмүүс Еховагийн илрэлтийг харж чаддаг байсан; мөн элчүүдийг харж чаддаг, зүүд зүүдэлдэг байлаа. Өнөөдрийн хүмүүс үзэгдлүүдийг, эсвэл элчүүдийг харж чаддаггүй, тиймээс тэдний мэдрэмж дэх алдаа мадаг ихэссэн. Өнөөгийн хүмүүст ямар нэгэн зүйл нэн зөв санагдаж, үүнийг хэрэгжүүлэх үед Ариун Сүнс тэднийг зэмлэдэггүй бөгөөд тэд дотроо тун их тайван байдаг. Дараа нь, харилцан яриа юм уу Бурханы үгийг уншсанаар л дамжуулан тэд өөрсдийнх нь буруу байсныг олж мэддэг. Нэг талаараа хүмүүст харагдах ямар ч элчүүд байхгүй, зүүд тун ховорхон байдаг бөгөөд хүмүүс тэнгэр дэх үзэгдлүүдийн юуг ч хардаггүй. Нөгөө талаар, Ариун Сүнс хүмүүсийн доторх Өөрийн зэмлэл болон сахилгажуулалтыг ихэсгэдэггүй; хүмүүст Ариун Сүнсний ажил тун хомс байдаг. Тиймээс хэрвээ хүмүүс Бурханы үгийг идэж, уудаггүй, үнэнийг бодитой байдлаар эрж хайдаггүй, хэрэгжүүлэлтийн замыг ойлгодоггүй бол юу ч олж авахгүй. Ариун Сүнсний ажлын зарчмууд дараах байдалтай байдаг: Тэрээр Өөрийнх нь ажилтай хамаагүй зүйлд ямар ч анхаарал хандуулдаггүй; хэрвээ ямар нэгэн зүйл Өөрийнх нь харьяалал дотор байхгүй бол Тэр бүр хэзээ ч хөндлөнгөөс оролцдоггүй, зохицуулдаггүй ба хүссэнээрээ хэрэг тарих боломжийг хүмүүст олгодог. Чи хүссэнээрээ үйлдэж болох боловч цочирдон мэгдэж, яахаа мэдэхгүй болох өдөр чамд ирнэ. Бурхан Өөрийн махбодод л нэгэн үзүүрт сэтгэлээр ажиллан, хүний ажилд хэзээ ч хөндлөнгөөс оролцдоггүй. Харин ч Тэр хүний ертөнцөөс зай барьж, хийх учиртай ажлаа хийдэг. Өнөөдөр чамайг буруу юм хийвэл Тэр зэмлэхгүй, маргааш сайн зүйл хийсэн ч чамайг шагнахгүй. Эдгээр нь хүний хэрэг явдал бөгөөд Ариун Сүнсний ажилтай өчүүхэн ч холбоогүй—энэ нь Миний ажлын цар хүрээн дотор огт байдаггүй.

Петр ажиллаж байх үедээ олон үг хэлж, ихээхэн ажил хийсэн. Үүний аль нь ч хүний санаанаас гараагүй байх боломжтой юу? Энэ нь бүхэлдээ Ариун Сүнснээс ирсэн байх боломжгүй. Петр бол ердөө л Бурханы бүтээл байсан, тэрээр дагагч байсан, мөн Есүс биш, Петр байсан бөгөөд тэдний мөн чанар адилхан байгаагүй юм. Петрийг хэдийгээр Ариун Сүнс илгээсэн боловч түүний хийсэн бүхэн Ариун Сүнснээс ирээгүй, учир нь эцсийн эцэст тэр бол хүн байсан билээ. Паул ч бас олон үг хэлж, чуулгануудад багагүй хэмжээний захидал бичсэн ба тэдгээрийн заримыг

Библид эмхэтгэсэн. Ариун Сүнс санал бодлоо илэрхийлээгүй, учир нь тэр үе бол Паулыг Ариун Сүнс ашиглаж байсан үе байлаа. Паул туршлага, мэдлэгтэй болж, тэдгээрийгээ бичиж тэмдэглээд, Эзэн доторх ах, эгч нартаа дамжуулжээ. Есүс ямар ч хариу үйлдэл үзүүлээгүй. Яагаад Ариун Сүнс тухайн үед түүнийг зогсоогоогүй вэ? Учир нь хүмүүсийн хэвийн бодлоос урган гардаг зарим нэг хольц байдаг; үүнээс зайлсхийх аргагүй. Нэмж хэлэхэд, түүний үйлдлүүд хөндлөнгөөс оролцох, саад болох хэмжээнд хүрээгүй. Хүн чанарын иймэрхүү ажил байх үед хүмүүсийн хувьд хүлээн зөвшөөрөхөд илүү амархан санагддаг. Хүний хэвийн бодол дахь хольц юунд ч саад болоогүй тохиолдолд тэдгээрийг хэвийн гэж тооцдог. Өөрөөр хэлбэл, хэвийн бодолтой хүмүүс бүгд тийм маягаар бодох чадвартай байдаг. Хүмүүс махан биед амьдарч байх үедээ өөрсдийн гэсэн бодолтой байдаг боловч эдгээрээс салах ямар ч аргагүй. Гэвч, Бурханы ажлыг хэсэг зуур туулж, зарим үнэнийг ойлгосны дараа ийм бодол улам цөөрнө. Илүү ихийг туулах үедээ тэд тодорхой харж чадах ба тиймээс саад болох нь арай багасна. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн төсөөлөл болон логик гаргалгааг няцаах үед хэвийн бус мэдрэмж нь багасна. Махан биед амьдардаг хүмүүс бүгд өөрсдийн гэсэн бодолтой байдаг боловч эцэстээ Бурхан, бодол нь өөрсдийг нь үймүүлж чадахааргүй хэмжээнд тэднийг аваачих ба амьдралдаа мэдрэмжид найдахаа больж, бодит биеийн хэмжээ нь өсөж, бодит байдал дээр Бурханы үгээр амьдрах чадвартай болж, тодорхойгүй, хий хоосон зүйл хийхээ болино, тэгээд тэд саад учруулах зүйлсийг хийхгүй. Ийм маягаар тэдний төөрөгдөл арилж, энэ үеэс эхлээд тэдний үйлдэл жинхэнэ биеийн хэмжээ нь байх болно.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН 1

Сатаны маш гүн гүнзгий завхруулсан хүн төрөлхтөн Бурхан байдаг гэдгийг мэддэггүй ба Бурханд шүтэн мөргөхөө больжээ. Анх Адам, Ева хоёрыг бүтээгдэх үед Еховагийн алдар болон гэрчлэл үргэлж байдаг байлаа. Гэхдээ завхруулагдсаныхаа дараа хүн алдар болон гэрчлэлийг алджээ, учир нь хүн бүр Бурханы эсрэг тэрсэлж, Түүнийг хүндлэхээ бүрмөсөн больсон юм. Өнөөдрийн байлдан дагуулалтын ажил нь, бүтээгдсэн зүйлсийн дунд гэрчлэлтэй байхын тулд бүх алдар суу, гэрчлэлийг буцаан авч, бүх хүнээр Бурханыг шүтүүлэхийн төлөө байдаг; энэхүү үе шатанд хийгдэх ажил нь энэ юм. Хүн төрөлхтнийг яг яаж байлдан дагуулдаг вэ? Хүнийг бүрэн дүүрэн үнэмшүүлэхийн тулд энэ үе шатны үгийн ажлыг ашигласнаар; хүнийг бүрэн ятгахын тулд илчлэлт, шүүлт, гэсгээлт, өршөөлгүй хараал ашигласнаар; хүний тэрслүү байдлыг илчилж, эсэргүүцлийг нь шүүснээр хийгддэг, ийнхүү тэрээр хүн төрөлхтний шударга бус, бузар булай байдлыг мэдэж, улмаар Бурханы зөвт зан чанарын товойлгогч болгон эдгээр зүйлийг ашиглаж чадна. Үндсэндээ эдгээр үгээр дамжуулан хүнийг байлдан дагуулж, бүрэн үнэмшүүлдэг. Үг бол хүн төрөлхтнийг эцэстээ байлдан дагуулах арга барил бөгөөд Бурханы байлдан

дагуулалтыг хүлээн зөвшөөрдөг бүх хүн Түүний үгийн цохилт, шүүлтийг хүлээн зөвшөөрөх ёстой. Өнөөгийн ярих үйл явц нь яг нарийндаа байлдан дагуулах үйл явц юм. Тэгвэл хүмүүс яг яаж хамтран ажиллах ёстой вэ? Эдгээр үгийг хэрхэн идэж, уухаа мэдэж, тэдгээрийг ойлгосноор. Хүмүүс хэрхэн байлдан дагуулагддаг тухайд гэвэл, энэ нь тэдний өөрсдөө хийж чадахгүй зүйл юм. Чи эдгээр үгийг идэж ууснаар дамжуулан өөрийн завхрал, бохир заваан, тэрслүү, зөв шударга бус байдлыг мэдэж авч, Бурханы өмнө сөхрөн унаж л чадна. Хэрвээ чи Бурханы хүслийг ухаарсныхаа дараа ч хэрэгжүүлж чаддаг бол, мөн үзэгдэлтэй байж, эдгээр үгэнд бүрэн захирагдаж чаддаг, өөрөө ямар ч сонголт хийдэггүй бол чи байлдан дагуулагдсан байх болно—энэ нь эдгээр үгийн үр дүн байна. Хүн төрөлхтөн яагаад гэрчлэлээ алдсан бэ? Хэн ч Бурханд итгэдэггүй учраас, хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан зай эзэлдэггүй учраас. Хүн төрөлхтнийг байлдан дагуулах нь хүн төрөлхтний итгэлийг сэргээх явдал юм. Хүмүүс дэлхий ертөнц рүү ухаан жолоогүй гүйхийг үргэлж хүсэж, хэтэрхий их итгэл найдвар өвөрлөж, ирээдүйнхээ төлөө дэндүү ихийг хүсэж, хэрээс хэтэрсэн шаардлага дэндүү их тавьдаг. Тэд үргэлж махан биеийн талаар бодож, төлөвлөдөг бөгөөд Бурханд итгэх замыг эрж хайх талаар огт сонирхдоггүй. Тэдний зүрх сэтгэлийг Сатан булаан авч, тэд Бурханыг хүндлэх хүндлэлээ алдсан ба Сатанд анхаарлаа хандуулдаг. Гэхдээ хүнийг Бурхан бүтээсэн. Тиймээс хүн гэрчлэлээ алдсан гэдэг нь Бурханы алдрыг алдсан гэсэн үг юм. Хүн төрөлхтнийг байлдан дагуулахын зорилго нь Бурханыг гэх хүний хүндлэлийн алдар сууг эргүүлэн авах явдал юм. Үүнийг ингэж хэлж болно: Амийг эрэлхийлдэггүй хүмүүс олон байдаг; амийг эрэлхийлдэг зарим хүн байдаг ч гэсэн тоо хэмжээгээрээ тун цөөхөн. Хүмүүс ирээдүйдээ санаа зовдог бөгөөд аминд ямар ч анхаарал хандуулдаггүй. Зарим нь Бурханы эсрэг тэрсэлж, эсэргүүцэж, ар хударгаар нь Түүнийг шүүдэг ба үнэнийг хэрэгжүүлдэггүй. Одоогоор энэ хүмүүсийг үл ойшоодог; одоохондоо энэ төрлийн тэрслүү хөвгүүдэд юу ч хийдэггүй боловч ирээдүйд чи харанхуйд амьдран, уйлж, шүдээ хавирах болно. Чи гэрэлд амьдарч байх үедээ эрхэм нандин байдлыг нь мэдэрдэггүй боловч харанхуй шөнөөр амьдармагцаа тэрхүү эрхэм нандин байдлыг ухаарч, дараа нь харамсана. Чамд одоо зүгээр санагдаж байгаа ч харамсах өдөр чинь ирнэ. Тэрхүү өдөр ирж, харанхуй нөмрөн авч, цаашид гэрэл гэж байхаа болих үед харамсахад хэтэрхий оройтсон байна. Чи өнөөдрийн ажлыг мөн л ойлгодоггүй болохоор одоо өөрт чинь байгаа цаг хугацааг нандигнаж чаддаггүй. Бүхий л орчлон ертөнцийн ажил эхэлмэгц буюу өнөөдөр Миний хэлж байгаа бүхэн биелэх үед олон хүн толгойгоо барин, шаналан уйлна. Ингэснээрээ тэд уйлж, шүдээ хавиран харанхуйд унасан байх бус уу? Амийг үнэхээр эрэлхийлдэг, бүрэн төгс болгуулсан бүхнийг ашиглаж болдог байхад ашиглагдахад тохирохгүй бүх тэрслүү хөвгүүд харанхуйд унана. Тэд Ариун Сүнсний ажилгүй, юуны ч учрыг олох чадваргүй байна. Тиймээс тэд шийтгэлд унаад тарчлан уйлна. Хэрвээ чи ажлын энэ үе шатанд сайтар зэвсэглэж, амиа өсгөсөн бол ашиглагдахад тохирох хүн юм. Харин муухан зэвсэглэсэн бол

хэдий чи ажлын дараагийн үе шатанд дуудагдсан ч гэсэн ашиглуулахад тохирохгүй—энэ үед өөрийгөө зэвсэглэхийг хүссэн ч гэсэн чамд өөр боломж олдохгүй. Бурхан явчихсан байх болно; тэгвэл одоо өмнө чинь байгаатай адил боломжийг олохын тулд чи хаашаа явах юм бэ? Бурханы биечлэн өгдөг сургуулилтыг хүлээн авахын тулд чи хаашаа явах юм бэ? Тэр үед Бурхан биечлэн үгээ хэлж, Өөрийн дуу хоолойг илэрхийлэхгүй; чи өнөөдөр хэлж байгаа зүйлийг л уншиж чадна—тэгвэл яаж амархан ойлгох юм бэ? Хожмын амьдрал яаж өнөөдрийнхөөс дээр байж чадах юм бэ? Тэр үед чи уйлж, шүдээ хавирангаа амьд үхлийг туулахгүй гэж үү? Одоо чамд ерөөл өгөгдөж байгаа боловч чи үүнийг хэрхэн эдлэхээ мэддэггүй; чи ерөөгдсөн байдал дунд амьдарч байгаа атлаа мэдэхгүй хэвээр үлддэг. Чи бол зовох заяатай гэдгийг энэ нь нотолдог! Өнөөдөр зарим хүн эсэргүүцэж, зарим нь тэрсэлж, зарим нь энэ тэрийг хийдэг бөгөөд Би үүнийг зүгээр л үл ойшоодог—гэхдээ яах гэж байгааг чинь мэддэггүй гэж бүү бод. Би та нарын мөн чанарыг ойлгодоггүй гэж үү? Яагаад Надтай сөргөлдсөөр байгаа юм бэ? Чи өөрийнхөө төлөө амь болон ерөөлийг эрэлхийлэхийн тулд Бурханд итгэдэг бус уу? Өөрийнхөө төлөө л итгэлтэй байдаг бус уу? Одоогийн хоромд Би зөвхөн үг хэлснээр байлдан дагуулалтын ажлыг хийж байгаа бөгөөд байлдан дагуулалтын энэ ажил дуусмагц төгсгөл чинь илэрхий болно. Би бүр илүү тодорхой хэлэх хэрэгтэй юу?

Өнөөдрийн байлдан дагуулалтын ажил нь хүний төгсгөл ямар байхыг ил болгохоор зорьдог. Өнөөдрийн шүүлт, гэсгээлт нь эцсийн өдрүүдийн агуу цагаан сэнтийн өмнөх шүүлт юм гэж яагаад хэлдэг вэ? Чи үүнийг харахгүй байна уу? Байлдан дагуулалтын ажил яагаад сүүлчийн үе шат вэ? Энэ нь яг нарийндаа төрөл бүрийн хүний төгсгөл ямар байхыг харуулахын төлөө байдаг бус уу? Энэ нь гэсгээлт, шүүлтээр байлдан дагуулах ажлын явцад, жинхэнэ нүүр царайгаа харуулж, дараа нь төрлийнхөө дагуу ангилагдах боломжийг хүн бүрд олгохын төлөө байдаг бус уу? Энэ нь хүн төрөлхтнийг байлдан дагуулж байгаа хэрэг гэж хэлэхийн оронд төрөл бүрийн хүний төгсгөл ямар байхыг харуулж байгаа хэрэг гэж хэлсэн нь дээр байж магад. Энэ нь, хүмүүсийн нүглийг шүүж, дараа нь хүний янз бүрийн төрлийг илчилж, улмаар ёрын муу, эсвэл зөв шударга эсэхийг нь шийдэх явдал юм. Байлдан дагуулалтын ажлын дараа сайныг шагнаж, мууг шийтгэх ажил явагддаг. Бүрэн дуулгавартай дагадаг буюу бүрмөсөн байлдан дагуулагдсан хүмүүсийг бүхий л орчлон ертөнцөд Бурханы ажлыг түгээх дараагийн алхамд байрлуулна; байлдан дагуулагдаагүй хүмүүсийг харанхуйд байрлуулах ба тэд гай гамшигтай тулгарна. Тиймээс хүн төрлийнхөө дагуу ангилагдаж, мууг үйлдэгчид муугийн бүлэгт ангилагдаж, дахин хэзээ ч нарны гэрэлд байхгүй бөгөөд зөв шударга хүмүүс сайнтай ангилагдан гэрлийг хүлээн авч, үүрд гэрэлд амьдарна. Бүх зүйлийн төгсгөл ойрхон байна; хүний төгсгөл нүдэнд нь тодорхой харагдсан бөгөөд бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдана. Тэгвэл хүмүүс дор бүрнээ төрлөөрөө ангилагдахын зовлонгоос хэрхэн зугтаж чадах вэ? Бүх зүйлийн төгсгөл ойртох үед

төрөл бүрийн хүний төгсгөл илчлэгддэг ба энэ нь бүхий л орчлон ертөнцийг байлдан дагуулах ажлын явцад (өнөөгийн ажлаас эхлээд байлдан дагуулалтын бүх ажлыг оролцуулан) хийгддэг. Бүх хүн төрөлхтний төгсгөлийг илчлэх илчлэлт нь гэсгээлтийн явцад, мөн эцсийн өдрүүдийн байлдан дагуулах ажлын явцад шүүх суудлын өмнө хийгддэг. Хүмүүсийг төрлийнх нь дагуу ангилах нь тэднийг анхдагч ангилал руу нь буцаах явдал биш, учир нь бүтээлийн цаг үед хүнийг бүтээхэд ердөө нэг төрлийн хүн байсан ба эрэгтэй, эмэгтэй хүний хооронд л зааг байсан. Олон өөр төрлийн хүн байгаагүй. Зөвхөн хэдэн мянган жилийн завхралын дараа л өөр өөр төрлийн хүмүүс гарч ирсэн бөгөөд зарим нь бузар диаволын эзэмшил дор, зарим нь муу ёрын диаволын эзэмшил дор, амийн замыг эрэлхийлдэг хүмүүс нь Төгс Хүчитийн ноёрхол дор гарч ирсэн. Ийм маягаар л хүмүүсийн дунд аажмаар анги давхарга бий болж, ингэснээр л хүмүүс, хүн төрөлхтний өнөр гэр бүл дотор хүмүүс тус тусын анги давхаргад хуваагдсан. Хүмүүс бүгд өөр өөр “эцэгтэй” болж эхэлсэн; хүн бүр бүхэлдээ Төгс Хүчитийн ноёрхол дор байдаг юм биш, учир нь хүн дэндүү тэрслүү. Зөв шударга шүүлт нь төрөл бүрийн хүний жинхэнэ төрхийг ил болгож, нууцлаг зүйл юу ч үлдээдэггүй. Гэрэлд хүн бүхэн жинхэнэ нүүр царайгаа харуулдаг. Өдгөө хүн анхных шигээ байхаа больж, өвөг дээдсийнх нь анхдагч төрх аль хэдийн үгүй болсон, учир нь Адам Евагийн тоо томшгүй олон үр удам хэдийнээ Сатанд олзлогдож, тэнгэрнарыг дахин хэзээ ч мэдэхээргүй болж, хүмүүс Сатаны бүх төрлийн хороор дүүрчээ. Тиймээс хүмүүс өөрсдөд нь тохирох хүрэх газартай байдаг. Түүнчлэн, өөр өөр хорынхоо үндсэн дээр тэд төрлөөрөө ангилагддаг, өөрөөр хэлбэл, тэд өнөөдөр байлдан дагуулагддаг хэмжээгээрээ ангилагддаг. Хүний төгсгөл нь дэлхий бүтээгдсэнээс хойш урьдчилан тогтоогдчихсон зүйл биш юм. Яагаад гэвэл, эхэндээ нэг л төрөл байсныг нийтэд нь “хүн төрөлхтөн” гэж нэрлэдэг байсан бөгөөд анх хүнийг Сатан завхруулаагүй байсан, мөн хүмүүс бүгд Бурханы гэрэлд амьдарч, ямар ч харанхуй нөмрөөгүй байв. Гэхдээ хүнийг Сатан завхруулсны дараа төрөл, зүйл бүрийн хүмүүс буюу нийтэд нь “хүн төрөлхтөн” гэж нэрлэдэг, эрэгтэй, эмэгтэй хүмүүсээс бүрдсэн гэр бүлээс гарсан төрөл, зүйл бүрийн хүмүүс газар дэлхий даяар тархсан. Тэднийг бүгдийг нь өвөг дээдэс нь удирдан хөтөлж, хамгийн дээд өвөг дээдэс болох эрэгтэй, эмэгтэй хүнээс бүрдсэн хүн төрөлхтнөөс (өөрөөр хэлбэл, хамгийн дээд өвөг дээдэс болох анхны Адам, Ева хоёроос) холдуулжээ. Тухайн үед газар дээр амьдрахдаа Еховагаар удирдуулж байсан цорын ганц хүмүүс нь израильчууд байсан билээ. Бүхий л Израилиас (анхдагч гэр бүлийн овгоос гэсэн үг) төрөл бүрийн хүмүүс үүсэн гарч, дараа нь Еховагийн удирдамжийг алдсан юм. Энэ эртний хүмүүс хүний ертөнцийн хэрэг явдлуудыг огт мэдэлгүй, өвөг дээдсээ даган, өөрсдийн эзэмшсэн газар нутагтаа амьдарч ирсэн нь өнөөг хүртэл үргэлжилжээ. Тиймээс тэд Еховагаас хэрхэн хөндийрч, өнөөдрийг хүртэл төрөл бүрийн бузар чөтгөр болон муу ёрын сүнсээр хэрхэн завхруулагдсан тухайгаа мэдэхгүй хэвээр байдаг. Өнөөг хүртэл хамгийн гүн гүнзгий завхарч, хордсон хүмүүс—эцэстээ аврагдаж чадахгүй хүмүүс—өөрсдийг нь

завхруулсан бузар диаволууд буюу өөрсдийн өвөг дээдэстэй хамт явахаас өөр сонголтгүй байх болно. Эцэстээ аврагдаж чадах хүмүүс хүн төрөлхтөнд тохирох хүрэх газар буюу аврагдаж, байлдан дагуулагдсан хүмүүст зориулсан төгсгөл рүү явна. Аврагдаж болох бүх хүнийг аврахын төлөө бүхнийг хийх болно—харин мэдрэмжгүй, засаршгүй хүмүүсийн хувьд, цорын ганц сонголт нь өвөг дээдсээ даган гэсгээлтийн ёроолгүй нүх рүү унах явдал юм. Чиний төгсгөл анхнаасаа урьдчилан тогтоогдсон ба одоо л илчлэгдлээ гэж бүү бод. Хэрвээ чи тэгж боддог бол хүн төрөлхтнийг анх бүтээх үед сатанлаг төрөл тусдаа бүтээгдээгүй гэдгийг мартаа юу? Адам, Ева хоёроос бүрдсэн (зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүн бүтээгдсэн гэсэн үг) цорын ганц хүн төрөлхтөн бүтээгдсэн гэдгийг мартчихаа юу? Хэрвээ чи анхнаасаа Сатаны үр удам байсан бол, Ехова хүнийг бүтээхдээ Өөрийн бүтээлд сатанлаг бүлгийг багтаасан гэсэн үг болох бус уу? Тэр үнэхээр тиймэрхүү зүйл хийх байсан гэж үү? Тэрээр Өөрийнхөө гэрчлэлийн төлөө хүнийг бүтээсэн; Өөрийнхөө алдрын төлөө хүнийг бүтээсэн. Санаатайгаар Өөрийг нь эсэргүүцэх Сатаны үр удмын төрлийг Тэр яагаад зориуд бүтээнэ гэж? Ехова яаж ийм зүйл хийж чадах юм бэ? Хэрвээ тэгсэн бол хэн Түүнийг зөвт Бурхан гэж хэлэх юм бэ? Та нарын зарим нь эцэстээ Сатантай хамт явах болно гэж одоо хэлж байгаа минь чи анхнаасаа Сатантай хамт байсан гэсэн үг биш; харин ч, Бурхан чамайг аврах гэж оролдсон ч гэсэн чи тэрхүү авралыг хүртэж чадахааргүй болтлоо доройтсон гэсэн үг юм. Чамайг Сатантай хамт ангилахаас өөр сонголт үгүй. Чи аврагдахын аргагүй учраас ийм байгаа бөгөөд Бурхан чамд шударга бус хандаж, хувь заяаг чинь санаатайгаар Сатаны биелэл болгон тогтоож, улмаар чамайг Сатантай хамт ангилж, зориуд зовоохыг хүсдэгээс болж байгаа юм биш. Энэ нь байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн биш. Хэрвээ чи ингэж итгэдэг бол ойлголт чинь маш өрөөсгөл байна! Байлдан дагуулахлтынэцсийн үе шат нь хүмүүсийг аварч, тэдний төгсгөлийг илчлэх учиртай. Энэ нь, шүүлтээр дамжуулан хүмүүсийн доройтлыг ил болгож, улмаар гэмшиж, өндийн босож, амь болоод хүний амьдралын зөв замыг эрэлхийлэхэд тэднийг хүргэх явдал юм. Энэ нь хөшүүн, маанаг хүмүүсийн зүрх сэтгэлийг сэрээж, шүүлтээр дамжуулан доторх тэрслүү байдлыг нь харуулахын төлөө байдаг. Гэсэн хэдий ч, хүмүүс гэмшиж чадахгүй, хүний амьдралын зөв замыг эрэлхийлж чадахгүй, эдгээр завхралыг хөсөр хаях чадваргүй хэвээр байвал аврагдах аргагүй бөгөөд Сатанд залгиулна. Хүмүүсийг аварч, бас тэдний төгсгөлийг харуулах нь Бурханы байлдан дагуулалтын ач холбогдол билээ. Сайн, муу төгсгөл нь бүгд байлдан дагуулалтын ажлаар илчлэгддэг. Хүмүүс аврагдах, хараагдах эсэх нь бүгд байлдан дагуулалтын ажлын явцад илчлэгддэг.

Эцсийн өдрүүд нь байлдан дагуулалтаар дамжуулан бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах үе юм. Байлдан дагуулах нь эцсийн өдрүүдийн ажил; өөрөөр хэлбэл, хүн бүрийн нүглийг шүүх нь эцсийн өдрүүдийн ажил билээ. Эс бөгөөс, хүмүүсийг яаж ангилж чадах юм бэ? Та нарын дунд хийгдэж байгаа ангилах ажил нь бүхий л орчлон ертөнц дэх ийм ажлын эхлэл юм. Үүний дараа, бүх газар нутгийн хүмүүс

болон бүх ард түмэн ч бас байлдан дагуулалтын ажлыг хүлээн авна. Энэ нь, бүтээл дэх хүн бүр төрлөөрөө ангилагдаж, шүүгдэхийн тулд шүүх суудлын өмнө захирагдана гэсэн үг юм. Хэн ч, юу ч энэхүү гэсгээлт, шүүлтийг туулахаас зугтаж чадахгүй, мөн төрлөөрөө ангилагддаггүй ямар ч хүн, ямар ч зүйл үгүй; хүн бүр ангилагдана, учир нь бүх зүйлийн төгсгөл ойртож, тэнгэр, газар бүгд төгсгөлдөө хүрсэн. Хүний оршин тогтнолын сүүлчийн өдрүүдээс хүн хэрхэн зугтаж чадах билээ? Тиймээс та нарын дуулгаваргүй үйл хэр удаан үргэлжилж чадах вэ? Эцсийн өдрүүд чинь ойрхон байгааг та нар харахгүй байна гэж үү? Бурханыг хүндэлж, Түүний гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүс Бурханы зөвт байдлын илрэлтийн өдрийг харахгүй байж яаж чадах юм бэ? Тэд сайн сайхан байдлын сүүлчийн шагналыг хүлээн авахгүй байж яаж чадах билээ? Чи сайныг хийдэг нэгэн үү, эсвэл ёрын мууг хийдэг нэгэн үү? Чи зөв шударга шүүлтийг хүлээн зөвшөөрөөд, дуулгавартай дагадаг нэгэн үү, эсвэл зөв шударга шүүлтийг хүлээн зөвшөөрөөд, дараа нь хараагддаг нэгэн үү? Чи шүүх суудлын өмнө гэрэлд амьдардаг уу, эсвэл Үхэгсдийн оронд харанхуйн дунд амьдардаг уу? Төгсгөл чинь шагнал байх уу, эсвэл шийтгэл байх уу гэдгийг хамгийн тодорхой мэддэг хүн чи өөрөө биш гэж үү? Бурхан бол зөвт гэдгийг хамгийн тодорхой мэдэж, хамгийн гүнзгий ойлгодог нэгэн чи биш гэж үү? Тэгвэл биеэ авч явах байдал болон зүрх сэтгэл чинь яг чухамдаа ямар вэ? Өнөөдөр чамайг байлдан дагуулахдаа Би, зан авир чинь сайн, муу эсэхийг үнэхээр нэг бүрчлэн хэлэх хэрэгтэй гэж үү? Чи Миний төлөө хэр ихийг орхисон бэ? Чи Надад хэр гүн гүнзгий шүтэн мөргөдөг вэ? Надад хэрхэн ханддагаа чи өөрөө хамгийн сайн мэддэг бус уу? Эцэстээ ямар үр дүнтэй тулгарахаа чи хэнээс ч илүү сайн мэдэж байх ёстой! Би чамд үнэнээсээ хэлж байна: Би зөвхөн хүн төрөлхтнийг бүтээж, чамайг бүтээсэн боловч та нарыг Сатанд өгөөгүй; Миний эсрэг тэрсэлж, Намайг эсэргүүцэж, улмаар Надаар шийтгүүлэхэд Би та нарыг зориуд хүргээгүй. Энэ бүх гай гамшиг, зовлон шаналал нь зүрх сэтгэл чинь хэтэрхий хатуу, биеэ авч явах байдал чинь хэтэрхий жигшүүртэй байснаас болоогүй гэж үү? Тэгвэл өөрсдөд чинь тулгарах төгсгөлийг та нар өөрсдөө тодорхойлдог бус уу? Та нар хэрхэн төгсөхөө зүрх сэтгэлдээ хэнээс ч илүү сайн мэддэг бус уу? Би хүмүүсийг байлдан дагуулдгийн шалтгаан нь тэднийг илчлэхийн төлөө, мөн чамайг илүү сайн аврахын төлөө байдаг. Энэ нь чамаар мууг үйлдүүлэхийн төлөө байдаггүй, чамайг зориуд сүйрлийн там руу алхуулахын төлөө ч байдаггүй. Цаг нь ирэх үед асар их зовлон чинь, уйлж, шүдээ хавирах чинь бүгд чиний нүглээс болохгүй гэж үү? Тиймээс сайн сайхан, эсвэл хорон муу чинь чамайг хамгийн сайн шүүдэггүй гэж үү? Чиний төгсгөл ямар байхын хамгийн сайн нотолгоо энэ биш гэж үү?

Өнөөдөр Би бүх тэрслүү зан чанарыг нь илчилж, бүх муу муухай байдлыг нь ил болгохын тулд Хятад дахь, Бурханы сонгосон хүмүүс дээр ажилладаг бөгөөд хэлэх хэрэгтэй бүхнээ хэлж байгаагийн минь нөхцөл байдал энэ юм. Дараа нь Би бүх орчлон ертөнцийг байлдан дагуулах ажлын дараагийн алхмыг хийхдээ бүхий л орчлон ертөнц дээрх хүн бүрийн зөв шударга бусыг шүүхдээ та нарыг шүүх шүүлтээ

ашиглана, учир нь хүмүүс та нар бол хүн төрөлхтний дундах тэрслүү хүмүүсийн төлөөлөгчид билээ. Урагшилж сайжирч чаддаггүй хүмүүс ердөө л товойлгогч, хүчин зүтгэгчид болно, харин сайжирч чаддаг хүмүүс ашиглагдана. Урагшилж сайжирч чадахгүй хүмүүс зөвхөн товойлгогч болж үйлчилнэ гэж Би яагаад хэлдэг вэ? Учир нь Миний өнөөгийн үг, ажил бүгд та нарын нөхцөл байдлыг онилдог, мөн та нар бүх хүн төрөлхтний дундах тэрслүү хүмүүсийн төлөөлөл, загвар болсон. Хожим нь Би та нарыг байлдан дагуулдаг эдгээр үгийг харийн улс орнуудад аваачиж, тэндхийн хүмүүсийг байлдан дагуулахад ашиглана, гэсэн ч чи тэдгээрийг олж аваагүй байх болно. Тэр нь та нарыг товойлгогч болгохгүй гэж үү? Бүх хүн төрөлхтний завхарсан зан чанар, хүний тэрслүү үйлс, хүний муухай дүр төрх, нүүр царай бүгд, өнөөдөр та нарыг байлдан дагуулахад ашигласан үгэнд тэмдэглэгддэг. Та нар үлгэр дуурайл, өмнөх жишээ учраас улс үндэстэн, урсгал бүрийн хүмүүсийг байлдан дагуулахын тулд Би эдгээр үгийг ашиглана. Гэхдээ Би та нарыг зориуд орхихоор төлөвлөөгүй; хэрвээ чи эрэл хайгуулаа сайн хийж чадалгүй, улмаар засаршгүй гэдгээ нотолбол зүгээр л хүчин зүтгэгч, товойлгогч болохгүй гэж үү? Миний мэргэн ухаан Сатаны арга мэхэнд үндэслэн хэрэгждэг гэдгийг Би нэгэнтээ хэлсэн. Яагаад Би тэгж хэлсэн бэ? Миний яг одоо хэлж, хийж байгаа зүйлийн ар дахь үнэн энэ биш гэж үү? Хэрвээ чи урагшлан сайжирч чадахгүй бол, хэрвээ чи төгс болгуулалгүй, харин ч шийтгүүлдэг бол товойлгогч болохгүй гэж үү? Магадгүй чи амьдралдаа асар их зовсон байж болох ч юу ч ойлгоогүй хэвээр байгаа; чи амийн талаар юу ч мэддэггүй. Гэсгээгдэж, шүүгдсэн хэдий ч чи огт өөрчлөгдөөгүй бөгөөд сэтгэлийн гүндээ амийг олж аваагүй. Чиний ажлыг турших цаг ирэх үед чи гал мэт ширүүн шалгалтыг болон бүр ч их гай зовлонг туулна. Энэхүү гал бүхий л оршихуйг чинь үнс нурам болгон хувиргана. Амийг эзэмшдэггүй хүн, дотроо өчүүхэн төдий ч шижир алтгүй хүн, завхарсан хуучин зан чанартайгаа зууралдсан хүн, товойлгогч байхыг ч сайн хийж чаддаггүй хүний хувьд чи яаж таягдан хаягдахгүй байж чадах юм бэ? Сохор зоосноос ч долоон дор үнэтэй, амьгүй хүн байлдан дагуулалтын ажилд хэрэгтэй байж чадна гэж үү? Тэр цаг ирэх үед өдөр хоногууд чинь Ноа болон Содомынхоос ч хэцүү байх болно! Тэр үед залбирлууд чинь чамд тус болохгүй. Авралын ажил хэдийнээ дуусчихсан байх үед чи яаж дараа нь буцаж ирээд, шинээр гэмшиж эхэлж чадах юм бэ? Бүх авралын ажил дуусмагц авралын ажил гэж байхаа болино; харин ёрын муу хүмүүсийг шийтгэх ажлын эхлэл л байх байна. Чи эсэргүүцэж, тэрсэлдэг бөгөөд ёрын муу гэдгийг нь мэддэг зүйлээ хийдэг. Чи хатуу чанга шийтгэлийн бай биш гэж үү? Өнөөдөр Би чиний төлөө энэ бүхнийг ойлгомжтой тайлбарлаж байна. Хэрвээ чи сонсохгүй гэж шийдвэл, хожим нь гай гамшиг тохиолдох үед харамсаж, итгэж эхэлсэн ч гэсэн хэтэрхий оройтохгүй гэж үү? Би чамд өнөөдөр гэмших боломж олгож байгаа ч чи тэгэхийг хүсэхгүй байна. Чи хэр удаан хүлээхийг хүсэж байгаа юм бэ? Гэсгээлтийн өдөр хүртэл үү? Урьдын гэм бурууг чинь Би өнөөдөр санадаггүй; Би чамайг ахин дахин уучилж, зөвхөн эерэг талыг чинь л харахын тулд чиний сөрөг талаас нүүр буруулдаг, учир нь Миний

одоогийн бүх үг болон ажил чамайг аврах учиртай бөгөөд Би чамд ямар ч муу санаа агуулаагүй. Гэсэн ч чи орохоос татгалздаг; чи сайн мууг ялгаж чаддаггүй, бас сайхан сэтгэлд хэрхэн талархахаа мэддэггүй. Ийм хүмүүс зүгээр л шийтгэл болон зөв шударга цээрлүүлэлт ирэхийг хүлээдэг бус уу?

Мосе хадыг цохиход Еховагийн хайрласан ус оргилсон нь түүний итгэлээс үүдэлтэй. Давид Ехова Намайг магтан лир хөгжим хөгжимдөж, зүрх сэтгэл нь баяр баяслаар дүүрдэг байсан нь түүний итгэлээс үүдэлтэй. Иов уул толгодыг бүрхсэн мал сүрэг, асар их эд хөрөнгөө алдан, бие нь яр шарханд баригдсан нь түүний итгэлээс үүдсэн. Ехова Миний дуу хоолойг сонсож, Ехова Миний алдар сууг харж чадсан нь ч түүний итгэлээс үүдэлтэй. Есүс Христийг Петр дагаж чадсан нь түүний итгэлээс улбаатай. Миний төлөө загалмайд цовдлогдож, алдар суут гэрчлэл хийж чадсан нь ч түүний итгэлээс улбаатай. Хүний Хүүгийн алдар суут дүрийг Иохан харсан нь түүний итгэлээс улбаатай. Эцсийн өдрүүдийн үзэгдлийг харсан нь түүний итгэлээс бүр ч их улбаатай. Харь үндэстний гэгдэх үй олон хүн Миний илчлэлийг олж авч, хүмүүсийн дунд ажлаа хийхээр махбодод эргэн ирсэн гэдгийг минь олж мэдсэн нь ч бас тэдний итгэлээс үүдэлтэй. Хатуу үгэнд минь цохиулдаг атлаа тэдгээрээс үүдэн тайтгарч, аврагддаг бүх хүн ч бас итгэлээсээ болж тэгдэг бус уу? Хүмүүс итгэлээсээ үүдэн маш ихийг хүлээн авсан бөгөөд энэ нь үргэлж ерөөл байдаггүй. Тэд Давидын мэдэрсэн аз жаргал, баяр хөөрийг хүлээн авахгүй, эсвэл Мосе шиг Еховагийн хайрласан усыг авахгүй байж магад. Жишээлбэл, Иов итгэлээсээ үүдэн Еховагаар ерөөгдсөн боловч бас гай гамшиг амссан. Чи ерөөгдсөн ч, эсвэл гай гамшиг амссан ч, аль аль нь ерөөлтэй үйл явдал юм. Итгэлгүйгээр чи байлдан дагуулалтын энэхүү ажлыг хүлээн авч чадахгүй, өнөөдөр нүдний чинь өмнө харагддаг Еховгийн үйл хэргийг харж бүр ч чадахгүй. Чи харж чадахгүй, тэр ч бүү хэл хүлээн авч чадахгүй байх болно. Эдгээр гай зовлон, гамшиг болон бүх шүүлт—хэрвээ эдгээр нь чамд тохиолдоогүй бол чи өнөөдөр Еховагийн үйл хэргийг харж чадах байсан уу? Өнөөдөр, итгэл нь чамд байлдан дагуулагдах боломж олгодог бөгөөд байлдан дагуулагдах нь чамд Еховагийн үйл хэрэг бүрд итгэх боломжийг олгодог. Итгэлийн улмаас л чи ийм гэсгээлт, шүүлтийг хүлээн авдаг. Энэ гэсгээлт, шүүлтээр дамжуулан чи байлдан дагуулагдаж, төгс болдог. Өнөөдөр чиний хүлээн авч байгаа ийм гэсгээлт, шүүлтгүйгээр итгэл чинь хий дэмий байх болно, учир нь чи Бурханыг мэддэггүй байна; Түүнд хэчнээн итгэсэн чинь хамаагүй, итгэл чинь бодит байдалд үндэслээгүй, хоосон илэрхийлэл төдий байна. Чамайг бүрэн дуулгавартай болгодог байлдан дагуулалтын энэ ажлыг хүлээн авсны дараа л чиний итгэл жинхэнэ, бат бөх болж, зүрх сэтгэл чинь Бурхан руу эргэдэг. “Итгэл” хэмээх энэхүү үгээс болж чи асар их шүүлт, хараал амсдаг ч гэсэн, жинхэнэ итгэлтэй байж, хамгийн жинхэнэ, хамгийн бодитой, хамгийн үнэ цэнтэй зүйлийг хүлээн авдаг. Яагаад гэвэл, зөвхөн шүүлтийн явцад л чи Бурханы бүтээлийн эцсийн хүрэх газрыг хардаг; энэхүү шүүлтээс л чи Бүтээгч хайрлагдах ёстой гэдгийг хардаг; ийм байлдан дагуулалтын ажлаас л чи Бурханы гарыг хардаг;

энэ байлдан дагуулалтаас чи хүний амьдралыг бүрэн ойлгож эхэлдэг; энэ байлдан дагуулалтаас чи хүний амьдралын зөв замыг олж авч, “хүн” гэдгийн жинхэнэ утга учрыг ойлгож эхэлдэг; зөвхөн энэ байлдан дагуулалтаас л чи Төгс Хүчитийн зөвт зан чанар болон үзэсгэлэнтэй сайхан, алдарт дүр төрхийг хардаг; энэхүү байлдан дагуулалтын ажлаас л чи хүний гарал үүслийг мэдэж авч, бүх хүн төрөлхтний “үхэшгүй мөнхийн түүхийг” ойлгодог; энэ байлдан дагуулалтаас л чи хүн төрөлхтний өвөг дээдэс болоод хүн төрөлхтний завхралын уг сурвалжийг танин мэдэж авдаг; энэ байлдан дагуулалтаас чи баяр хөөр, тайтгарал, түүнчлэн эцэс төгсгөлгүй цээрлүүлэлт, сахилгажуулалт болон Бүтээгчээс Өөрийн бүтээсэн хүн төрөлхтөнд өгсөн зэмлэлийн үгийг хүлээн авдаг; энэ байлдан дагуулалтын ажлаас чи ерөөл хүлээн авдаг, мөн хүний хүртэх ёстой гай гамшгийг хүлээн авдаг… Энэ нь бүгд өчүүхэн итгэлээс чинь болж байгаа бус уу? Эдгээр зүйлийг олж авсны дараа итгэл чинь өсөөгүй гэж үү? Чи үлэмж ихийг олж аваагүй гэж үү? Бурханы үгийг сонсож, Бурханы мэргэн ухааныг харснаар үл барам, чи бас ажлын алхам бүрийг биечлэн туулсан. Хэрвээ итгэлгүй байсан бол ийм төрлийн гэсгээлт, эсвэл ийм төрлийн шүүлтийг амсахгүй байх байсан гэж чи хэлж магадгүй. Гэвч итгэлгүйгээр чи Төгс Хүчитээс ийм гэсгээлт, ийм халамжийг хүлээн авч чадахгүйгээр зогсохгүй, Бүтээгчтэй уулзах боломжоо үүрд алдах байсан гэдгээ мэдэж байх ёстой. Чи хүн төрөлхтний гарал үүслийг хэзээ ч мэдэхгүй, хүний амьдралын ач холбогдлыг хэзээ ч ойлгохгүй байх байсан. Бие чинь үхэж, сүнс чинь одсон ч гэсэн чи Бүтээгчийн бүх үйл хэргийг мөн л ойлгож чадахгүй байх байсан, тэр ч бүү хэл, Бүтээгч хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа газар дээр үнэхээр агуу ажил хийсэн гэдгийг мэдэхгүй байх байв. Түүний бүтээсэн энэхүү хүн төрөлхтний нэгэн гишүүн болохын хувьд чи ийм маягаар мунхаглан харанхуй руу унаж, мөнхийн шийтгэл амсахыг хүсэж байна уу? Хэрвээ чи өөрийгөө өнөөдрийн гэсгээлт, шүүлтээс салгавал чамд юу тулгарах вэ? Өнөөгийн шүүлтээс салмагц энэхүү хүнд хэцүү амьдралаас зугтаж чадна гэж чи бодож байна уу? Хэрвээ чи “энэ газрыг” орхиж явбал зовлонт тарчлаан, эсвэл диаволын учруулсан харгис хүчирхийлэлтэй л тулгарна гэдэг худлаа гэж үү? Тэвчихийн аргагүй өдөр, шөнүүд тулгарч магад бус уу? Өнөөдрийн энэ шүүлтээс л зугтдаг учраас чи ирээдүйн тарчлаанаас үүрд зайлж чадна гэж бодож байна уу? Чиний замд юу тулгарах вэ? Энэ нь үнэхээр чиний хүсдэг Диваажингийн орон байх юм гэж үү? Чи одоогийнх шигээ бодит байдлаас зугтсанаар хожмын мөнхийн гэсгээлтээс зайлж чадна гэж бодож байна уу? Өнөөдрөөс хойш чи ийм боломж, ийм ерөөлийг дахиад ер нь олж чадах уу? Гай гамшиг чамд тохиолдох үед чи тэдгээрийг олж чадах уу? Бүх хүн төрөлхтөн амралтад орох үед чи тэдгээрийг олж чадах уу? Өнөөгийн аз жаргалтай амьдрал болон эв зохицолтой бяцхан гэр бүл чинь ирээдүйн мөнхийн хүрэх газрыг чинь орлож чадах уу? Хэрвээ чи жинхэнэ итгэлтэй бол, мөн хэрвээ чи итгэлээсээ үүдэн асар ихийг олж авдаг бол тэр бүхэн нь бүтээгдсэн зүйл болох чиний олж авах ёстой, бас анхнаасаа чамд байх ёстой байсан зүйл юм. Ийм байлдан дагуулалт чиний итгэл болон аминд хамгийн их ач тустай.

Өнөөдөр чи, байлдан дагуулагддаг хүмүүсээс Бурхан юу шаарддагийг, төгс болгуулдаг хүмүүст хандах Түүний хандлага ямар болохыг, мөн одоо юунд орох ёстойгоо ойлгох хэрэгтэй. Зарим зүйлийг нь чи бага зэрэг л ойлгох хэрэгтэй. Нууцын тухай зарим үгийг чи судалж шинжлэх хэрэггүй; тэдгээр нь аминд тийм ч их нэмэргүй бөгөөд хальт харахад л болно. Тэгээд Адам Ева хоёрын нууц гэх мэт нууцуудыг буюу тухайн үед Адам, Ева хоёр ямар байсан, Бурхан өнөөдөр ямар ажил хийхийг хүсдэг зэргийг уншиж болно. Хүнийг байлдан дагуулж, төгс болгохдоо Бурхан түүнийг Адам, Ева хоёрын байсан байдалд буцаан аваачихыг хүсдэгийг чи ойлгох хэрэгтэй. Бурханы стандартад нийцэхийн тулд хүрэх ёстой төгс төгөлдрийн түвшний талаар сайн мэддэг байж, үүнд хүрэхээр хичээх ёстой. Энэ нь чиний хэрэгжүүлэлттэй хамаатай бөгөөд чиний ойлгох ёстой зүйл юм. Эдгээр асуудлын тухайд чи Бурханы үгийн дагуу орохоор эрж хайхад хангалттай. “Хүн төрөлхтний хөгжлийн түүх хэдэн арван мянган жилийн тэртээгээс эхэлсэн” гэдгийг унших үедээ чи сониуч болдог тул ах эгч нарын хамтаар хариулт олохоор оролддог. “Хүн төрөлхтний хөгжил зургаан мянган жилийн өмнөөс эхэлсэн гэж Бурхан хэлдэг биз дээ? Тэгвэл энэ хэдэн арван мянган жил гэдэг нь юу гэсэн үг вэ?” Энэ асуултын хариултыг олохоор оролдох нь ямар хэрэгтэй юм бэ? Бурхан Өөрөө хэдэн арван мянган жилийн турш, эсвэл хэдэн зуун сая жилийн турш ажилласаар ирсэн—энэ талаар мэдэх чинь Түүнд үнэхээр хэрэгтэй гэж үү? Энэ нь бүтээгдсэн зүйл болох чиний мэдэх хэрэгтэй зүйл биш. Чи иймэрхүү яриаг цухасхан авч үзэхэд л болно; үүнийг үзэгдэл шиг ойлгохоор бүү оролд. Чи өнөөдөр юунд орж, ойлгох ёстойгоо мэддэг байх хэрэгтэй, тэгээд энэ талаар баттай ойлгодог байх хэрэгтэй. Тэр үед л чи байлдан дагуулагдана. Дээрхийг уншсаны дараа чамд хэвийн хариу үйлдэл байх ёстой: Бурхан асар их түгшиж байгаа, Тэрээр биднийг байлдан дагуулж, алдар суу болон гэрчлэлийг олж авахыг хүсдэг, тэгвэл бид Түүнтэй хэрхэн хамтран ажиллах ёстой вэ? Түүгээр бүрэн байлдан дагуулагдаж, Түүний гэрчлэл болохын тулд бид юу хийх ёстой вэ? Бурханд алдар суу олж авах боломж олгохын тулд юу хийх ёстой вэ? Өөрсдийгөө Сатаны эзэмшил дор биш, харин Бурханы ноёрхол дор амьдруулахын тулд бид юу хийх ёстой вэ? Энэ нь хүмүүсийн бодож байх ёстой зүйл юм. Бурханы байлдан дагуулалтын ач холбогдлын талаар та нар дор бүрнээ тодорхой мэдэж байх ёстой. Тэр бол та нарын хариуцлага. Ингэж тодорхой ойлгосныхоо дараа л та нар оролттой байж, ажлын энэ үе шатыг мэдэж, бүрэн дуулгавартай болох болно. Эс бөгөөс, та нар жинхэнэ дуулгавартай байдалд хүрэхгүй.

ЧИ ЯАГААД ТОВОЙЛГОГЧ БАЙХЫГ ХҮСДЭГГҮЙ ЮМ БЭ?

Байлдан дагуулагддаг хүмүүс бол товойлгогчид бөгөөд хүмүүс төгс болгуулсныхаа дараа л эцсийн өдрүүдийн ажлын үлгэр жишээ, загвар болдог. Бүрэн төгс болгуулахаасаа өмнө тэд бол товойлгогчид, хэрэгсэл, мөн түүнчлэн хүчин зүтгэгчид

юм. Бурханаар бүрэн байлдан дагуулагдсан хүмүүс бол Түүний удирдлагын ажлын биелэлт, мөн үлгэр жишээ, загвар билээ. Тийм хүмүүсийг дүрслэхэд ашигласан энэ үг шалихгүй байж болох ч олон сонирхолтой түүхийг илчилдэг. Өчүүхэн итгэлтэй та нар үргэлж шалихгүй цолны төлөө нүүрээ минчийтэл маргалдаж, заримдаа үүнээс үүдэн харилцаа чинь ч сүйрдэг. Хэдийгээр энэ нь ердөө жаахан цол боловч та нарын бодол санаанд, та нарын итгэлд энэ нь авцалдаагүй нэг нэрээс хавьгүй илүүгээр үл барам, харин хувь заяатай чинь хамаатай чухал хэрэг явдал юм. Иймээс эрүүл ухаангүй хүмүүс иймэрхүү жаахан юмнаас болж үргэлж асар их хохирол амсана—энэ бол ялихгүй юманд ямааны гарз гаргаж байгаа хэрэг мөн. Та нар шалихгүй цолноос болж зугтан одоод, хэзээ ч эргэж ирэхгүй. Энэ нь амийг чухал биш гэж үздэгээс чинь болж байгаа бөгөөд та нар ямар нэрээр дуудагдах тухайдаа хэтэрхий их ач холбогдол өгдөг. Иймээс сүнслэг амьдралдаа, бүр бодит амьдралдаа ч гэсэн та нар байр суурийн талаарх үзлээсээ болж олон ярвигтай, хачин түүхийг үргэлж бий болгоно. Та нар үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байж магадгүй ч бодит амьдралд чинь ийм хүмүүс үнэхээр байдаг гэдгийг Би хэлье, гэхдээ та нар хараахан нэг нэгээрээ илчлэгдээгүй. Ийм төрлийн зүйлс та бүхний амьдралд тохиолдож байсан. Хэрвээ чи үүнд итгэхгүй бол доор буй, нэг эгчийн (эсвэл ахын) амьдралын товч дүрслэлийг хар. Тэр хүн үнэндээ чи ч байх боломжтой, эсвэл таньдаг хүн чинь байж ч магадгүй. Хэрвээ Би андуураагүй бол энэхүү товч дүрслэл нь чамд байсан туршлагыг дүрсэлдэг. Энэхүү дүрслэлд юу ч дутагдаагүй, ганц бодол, санаа ч орхигдоогүй, харин бүхэлдээ энэ түүхэнд тэмдэглэгдсэн. Хэрвээ итгэхгүй бол эхлээд зүгээр л уншаад үз.

Энэ бол “сүнслэг хүний” нэгэн жаахан туршлага юм.

Чуулганы ах эгч нарын хийсэн олон зүйл Бурханы хүсэлтэй нийцэхгүй байгааг хараад тэр эгч бачимдаж, тэднийг ийнхүү загнаж эхэлжээ: “Өөдгүй амьтад! Та нарт ер нь мөс чанар алга уу? Яагаад та нар үнэндээ мөс чанаргүй зүйл хийж байгаа юм бэ? Хүссэн болгоноо хийхийн оронд яагаад үнэнийг эрж хайдаггүй юм бэ?… Би та нарт ингэж хэлж байгаа ч бас өөрийгөө үзэн ядаж байна. Бурхан тэсэн ядаж байгааг хараад би дотроо шатдаг. Надад Бурханы даалгасан ажлыг бүрэн биелүүлэхийг би үнэхээр хүсдэг, бас та нарт үйлчлэхийг үнэхээр хүсдэг. Гэхдээ яг одоо бол би маш сул дорой байна. Бурхан бидэнд маш их цаг зарцуулж, маш олон үг хэлсэн боловч бид одоо ч хэвээрээ л байна. Зүрх сэтгэлдээ би Бурханд хэтэрхий их өртэйгөө үргэлж мэдэрдэг…” (Үргэлжлүүлэн ярьж чадалгүй, уйлж эхлэв.) Дараа нь тэр ийнхүү залбирч эхэллээ: “Өө Бурхан минь! Надад хүч чадал өгч, миний сэтгэлийг урьдынхаасаа ч их хөдөлгөөч гэж би Танаас гуйж байна, Таны Сүнс надад ажиллах болтугай. Би Тантай хамтран ажиллахад бэлэн байна. Эцэст нь Та алдрыг олж авах л юм бол амиа өгөх ёстой байсан ч гэсэн, яг одоо би өөрийгөө бүхэлд нь Танд өгөхөд бэлэн байна. Бид асар их магтаал өргөхийг хүсэж байна, ингэснээр ах эгч нар Таны ариун нэрийг магтаж, Таныг алдаршуулж, Таныг илэрхийлж, Таны ажил үнэн зөв гэдгийг тогтоож, Таны үүрдэг ачаанд бүх анхаарлаа хандуулахын тулд

баяр хөөртэйгөөр дуулж, бүжиглэж чадна…” Тэр ийм маягаар чин сэтгэлээсээ залбирсан бөгөөд Ариун Сүнс үнэхээр түүнд ачаа өгчээ. Энэ хугацаанд тэр эгч маш их ачаа үүрч, бүхэл өдөржингөө уншиж, бичиж, сонсож өнгөрүүллээ. Тэр чадах чинээгээрээ завгүй байв. Түүний сүнслэг байдал гойд сайн байсан бөгөөд зүрх сэтгэлдээ үргэлж эрч хүчтэй, ачаатай байсан юм. Хааяа хааяа сул дорой болж, хана мөргөж байсан боловч тун удалгүй хэвийн байдалдаа эргэн ордог байжээ. Иймэрхүү хэсэг хугацааны дараа түүний ахиц тун хурдацтай байдаг байсан бөгөөд тэрээр Бурханы олон үгийг ойлгож чадсанаас гадна магтан дуунуудыг хурдан сурч—ерөнхийдөө түүний сүнслэг байдал гойд сайн байв. Чуулган дахь олон зүйл Бурханы хүсэлтэй нийцэхгүй байгааг харах үедээ тэр бачимдаж: “Энэ чинь үүрэгтээ үнэнч байгаа хэрэг үү? Та нар яагаад ийм жаахан төлөөс ч төлж чаддаггүй юм бэ? Хэрвээ та нар үүнийг хийхийг хүсэхгүй бол би хийнэ …” хэмээн ах эгч нараа зэмлэжээ.

Ачаатай байх үед Ариун Сүнс ажиллах тусам түүнд төдий чинээ өөртөө итгэлтэй санагдаж байв. Тэр хааяа зарим нэг бэрхшээлтэй тулгарч, идэвхгүй болж байсан боловч үүнийг давж гарч чаддаг байлаа. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнсний ажлыг туулах үед, нөхцөл байдал нь гайхалтай байх үед ч гэсэн тэр эгч тодорхой нэг бэрхшээл, бага зэргийн сул дорой байдлаас зайлсхийж мөн л чадаагүй. Ийм зүйлс зайлшгүй тохиолддог боловч тун удалгүй тэр тэдгээр байдлаас гарч чаддаг байлаа. Сул дорой байдлыг мэдрэх үедээ залбираад биеийн хэмжээ нь үнэхээр хангалтгүй гэдгийг мэдэрдэг байсан боловч Бурхантай хамтран ажиллахад бэлэн байв. Бурхан юу ч хийсэн бай, Түүний хүслийг хангалуун байлгаж, Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагахад бэлэн байлаа. Түүний талаар тодорхой санал бодол болон сэжиг таамагтай зарим хүн байсан ч тэрээр өөрийгөө хойш тавьж, идэвх санаачилгатайгаар тэдэнтэй хамт нөхөрлөж чаддаг байсан юм. Ариун Сүнс хэвийн ажлаа гүйцэтгэх үеэр хүмүүсийн байр байдал иймэрхүү байдаг. Хэсэг хугацааны дараа Бурханы ажил өөрчлөгдөж эхэлсэн бөгөөд хүмүүс бүгдээрээ ажлын өөр алхамд орж, Бурхан тэдэнд өөр шаардлага тавьсан юм. Иймээс хүмүүст шинэ шаардлага тавьсан шинэ үг хэлсэн байв: “…Би та нарыг зөвхөн үзэн яддаг, хэзээ ч ерөөдөггүй. Надад та нарыг ерөөх бодол хэзээ ч байгаагүй, бүрэн төгс болгох бодол ч байгаагүй, учир нь та нар хэтэрхий тэрслүү. Та нар шударга бус агаад ов мэхтэй, хэв чанараар дутмаг, дорд байр суурьтай учраас Миний хараанд юм уу Миний зүрх сэтгэлд хэзээ ч байгаагүй. Миний ажил та нарыг яллах ганцхан санаа зорилготой хийгддэг; Миний гар та нараас хэзээ ч хол байгаагүй, Миний гэсгээлт ч хол байгаагүй. Би та нарыг үргэлжлүүлэн шүүж, хараасан. Та нарт Миний тухай ямар ч ойлголт байхгүй учраас Миний уур хилэн үргэлж та нар дээр байсан. Би үргэлж та нарын дунд ажилласан хэдий ч та нарт хандах Миний хандлагыг та нар мэдэх ёстой. Энэ нь гагцхүү зэвүүцэл л байдаг—өөр ямар ч хандлага юм уу санал байхгүй. Та нар Миний мэргэн ухаан ба Миний агуу хүч чадлыг товойлгогч болон ажиллаасай л гэж Би хүсдэг. Та нар бол Миний товойлгогчдоос өөр юу ч

биш, учир нь та нарын тэрслүү байдлаар Миний зөвт байдал илчлэгддэг. Өөрийн ажлын төлөө Би та нарыг товойлгогч болгож, Өөрийн ажлын хавсралт болгон ажиллуулна…” “Хавсралт” болон “товойлгогч” хэмээх үгсийг хармагцаа тэр эгч ингэж бодож эхэлсэн: “Ийм үгийг би яаж дагах юм бэ? Ийм төлөөс төлчхөөд би товойлгогч хэвээр байна. Товойлгогч нь ердөө үйлчлэл үзүүлэгч биш гэж үү? Бид үйлчлэл үзүүлэгч болохгүй, харин Бурханы ардууд болно гэж өмнө нь хэлж байсан атал өнөөдөр бид үйлчлэл үзүүлэгчдийн үүрэгтэй байгаа бус уу? Үйлчлэл үзүүлэгчдэд амь байдаггүй бус уу? Би хэчнээн их зовлон туулсан ч, Бурхан үүний төлөө намайг магтахгүй! Товойлгогч байж гүйцсэний минь дараа тэгээд л дуусах бус уу?…” Тэр эгч энэ талаар бодох тусмаа төдий чинээ их гутарчээ. Тэр чуулганд ирээд ах эгч нарынхаа байдлыг харах үедээ бүр ч тавгүйтэж: “Та нар зүгээр биш! Би бас зүгээр биш байна! Би сөрөг болчихлоо. Өө! Яах ч билээ дээ? Бурхан одоо ч биднийг хүсдэггүй. Ийм төрлийн ажил хийснээрээ Тэр биднийг сөрөг болгохгүй байна гэж байхгүй. Миний юу болохгүй байгааг би мэдэхгүй байна. Би бүр залбирахыг ч хүсэхгүй байна. Ямартай ч би яг одоо зүгээр биш байна, дотоод хүчээ дайчилж үнэхээр чадахгүй нь. Би олон удаа залбирсан боловч үргэлжлүүлж бас л чадахгүй, үргэлжлүүлэхийг ч хүсэхгүй байна. Би ингэж л харж байна. Бурхан биднийг товойлгогчид гэж хэлдэг, тэгвэл ‘товойлгогчид’ нь үйлчлэл үзүүлэгчид төдий биш гэж үү? Бурхан биднийг Түүний хөвгүүд, эсвэл ардууд биш, харин товойлгогчид гэж хэлдэг. Бид Түүний ууган хөвгүүд байх нь байтугай, хөвгүүд нь ч биш. Бид юу ч биш, ердөө л товойлгогчид. Хэрвээ бид тийм юм бол таатай үр дүнтэй байх боломжтой гэж үү? Товойлгогчдод ямар ч найдвар байхгүй, учир нь тэдэнд амь байдаггүй. Хэрвээ бид Түүний хөвгүүд, Түүний ардууд байсан бол найдвар байх байсан—бид бүрэн төгс болгуулж чадах байсан. Товойлгогчид Бурханы амийг агуулж чадах уу? Өөрийнх нь төлөө үйлчлэл үзүүлдэг хүмүүст Бурхан амь оруулж чадах уу? Түүний хайрладаг хүмүүс бол Түүний амьтай хүмүүс бөгөөд Түүний амьтай хүмүүс л Түүний хөвгүүд, ардууд юм. Хэдийгээр би сөрөг, сул дорой байгаа ч та бүхнийг сөрөг биш гэж найдаж байна. Ийм маягаар ухарч няцан, сөрөг байх нь Бурханы хүслийг хангалуун байлгаж чадахгүй гэдгийг мэдэж байгаа ч би товойлгогч байхыг хүсэхгүй байна. Би товойлгогч байхаас айдаг. Ямартай ч надад иймхэн л эрч хүч байгаа бөгөөд би одоо цааш үргэлжлүүлэн явж чадахгүй. Та нарын нэг нь ч над шиг байхгүй, харин надаас тодорхой хэмжээний урам зориг олж авч чадна гэж би найдаж байна. Надад үхчихдэг болоосой гэж ч санагдаж байна! Үхэхээсээ өмнө би та нарт эцсийн үгээ үлдээе—та нар эцсээ хүртэл товойлгогч болон үйлдэж чадна гэж би найдаж байна; эцэст нь Бурхан магадгүй товойлгогчдыг магтах байх…” Ах эгч нар үүнийг харах үедээ: “Эгч яаж ийм сөрөг байж чадаж байна аа? Сүүлийн хэдэн өдөр зүв зүгээр байсан биз дээ? Яагаад гэнэтхэн ийм хүйтэн болчхов оо? Яагаад хэвийн биш байна вэ?” гэж гайхжээ. Тэрээр: “Намайг хэвийн биш байна гэж бүү хэл. Үнэндээ би зүрх сэтгэлдээ бүхнийг тодорхой мэдэж байгаа. Бурханы хүслийг хангалуун байлгаагүй гэдгээ би

мэднэ, гэхдээ энэ нь би Түүний товойлгогч болохыг хүсэхгүй байгаагаас л болсон бус уу? Би ямар ч муу юм хийгээгүй. Магадгүй нэг өдөр Бурхан ‘товойлгогчдын’ цолыг ‘бүтээл’ болгож, түүгээр ч үл барам чухалчлан ашигладаг бүтээлээ болгон өөрчлөх байх. Энд бага зэрэг найдвар байгаа бус уу? Та нар сөрөг, урам хугарсан байдалтай байлгүй, Бурханыг үргэлжлүүлэн дагаж, товойлгогч болон үйлчлэхийн тулд чадах бүхнээ хийж чадна гэж би найдаж байна. Ямартай ч би үргэлжлүүлж чадахгүй. Миний үйлдлээр бүү хязгаарлагд” гэж хэлсэн. Бусад хүмүүс түүнийг сонсоод: “Чи Түүнийг дагахаа больсон ч гэсэн бид үргэлжлүүлнэ, учир нь Бурхан бидэнд хэзээ ч шударга бус хандаж байгаагүй. Сөрөг байдлаас чинь болж бид хязгаарлагдахгүй” гэжээ.

Хэсэг хугацааны ийм туршлагын дараа тэр эгч товойлгогч байх тухайд сөрөг байдалтай хэвээр байсан болохоор Би түүнд: “Чамд Миний ажлын талаар ямар ч ойлголт алга. Миний үгийн дотоод үнэн, мөн чанар, эсвэл зорьсон үр дүнгийн талаар ямар ч ойлголт алга. Чи Миний ажлын зорилгыг ч, мэргэн ухааныг ч мэддэггүй. Чамд Миний хүслийн талаар ямар ч ухаарал алга. Чи товойлгогч учраас ухарч няцахаа л мэддэг—байр суурийн төлөөх чиний хүсэл хэтэрхий их! Чи ямар тэнэг юм бэ! Урьд нь Би чамд маш ихийг хэлсэн. Чамайг төгс болгоно гэж хэлсэн; чи мартчихаа юу? Товойлгогчдын тухай ярихаасаа ч өмнө төгс болгуулах тухай яриагүй гэж үү?” гэсэн юм. “Түр хүлээгээрэй, би энэ талаар бодож үзье. Тийм ээ, тэр үнэн! Товойлгогчдын талаар ярихаасаа өмнө Та тэдгээр зүйлийг хэлсэн шүү!” “Төгс болгуулах тухай ярихдаа Би хүмүүс байлдан дагуулагдсаныхаа дараа л төгс болгуулна гэж хэлсэн биз дээ?” “Тийм!” “Миний үг чин сэтгэлийнх байгаагүй гэж үү? Тэдгээрийг үнэнч шударгаар хэлээгүй гэж үү?” “Тийм ээ! Та хэзээ ч, ямар ч хуурамч зүйл хэлж байгаагүй Бурхан—хэн ч үүнийг үгүйсгэж зүрхлэхгүй. Гэхдээ Таны ярьдаг арга зам хэтэрхий олон.” “Миний ярих арга зам ажлын өөр өөр алхмын дагуу өөрчлөгддөггүй гэж үү? Миний хэлдэг зүйл чиний хэрэгцээнд үндэслэн хийгдэж, хэлэгддэггүй гэж үү?” “Та хүмүүсийн хэрэгцээний дагуу ажиллаж, хэрэгтэй зүйлээр нь тэднийг хангадаг. Энэ худлаа биш!” “Тэгвэл чамд Миний хэлсэн зүйлс ач тустай байгаагүй гэж үү? Миний гэсгээлт чиний төлөө байгаагүй гэж үү?” “Үүнийг миний төлөө гэж Та яаж хэлж чадаж байна аа! Та намайг бараг үхтэл минь гэсгээсэн—би цаашид амьдрахыг хүсэхгүй байна. Өнөөдөр Та энийг хэлж, маргааш тэрийг хэлнэ. Та намайг төгс болгож байгаа нь миний төлөө гэдгийг би мэдэж байгаа ч Та намайг төгс болгоогүй—Та намайг товойлгогч болгоод, гэсгээсээр байдаг. Та намайг үзэн яддаг, тийм биз дээ? Хэн ч Таны үгэнд итгэж зүрхэлдэггүй, Таны гэсгээлт намайг аврахын тулд биш, харин зүрх сэтгэл дэх үзэн ядалтаа л шийдвэрлэхийн төлөө байдаг гэдгийг одоо л би тодорхой харлаа. Өмнө нь Та надаас үнэнийг нуусан, Та намайг төгс болгох бөгөөд гэсгээлт бол намайг төгс болгохын төлөө байдаг гэж Та хэлсэн. Иймээс би үргэлж Таны гэсгээлтэд дуулгавартай байсан; өнөөдөр товойлгогч цолтой байх юм гэж би хэзээ ч төсөөлөөгүй. Бурхан минь, Та намайг өөр ямар нэг зүйл болгон ажиллуулсан бол дээр байх байсан бус уу? Та надад

товойлгогчийн малгай өмсгөх ёстой гэж үү? Би хаанчлалын хаалгач байхыг ч зөвшөөрнө. Би хаа сайгүй гүйж, өөрийгөө зарлагадсан ч эцэст нь гар хоосон байна—надад сохор зоос ч алга. Гэтэл одоо ч гэсэн Та намайг Өөрийн товойлгогч болгон ажиллуулна гэж хэлж байна. Би бүр яаж царайгаа харуулж чадах юм бэ?” “Чи юу яриад байна аа? Би урьд нь маш их шүүлтийн ажил хийсэн, чи үүнийг ойлгодоггүй гэж үү? Чи өөрийгөө үнэхээр ойлгодог уу? ‘Товойлгогч’ цол ч бас үгийн шүүлт биш гэж үү? Товойлгогчийн тухай бүх яриа минь ч бас арга барил, чамайг шүүх арга зам гэж чи боддог уу? Тэгвэл чи Намайг яаж дагах юм бэ?” “Таныг яаж дагахаа би төлөвлөөгүй л байна! Эхлээд би үүнийг мэдэх ёстой: Би товойлгогч уу, үгүй юү? Товойлгогчид ч бас төгс болгуулж болох уу? ‘Товойлгогч’ хэмээх цолыг өөрчилж болох уу? Товойлгогч байснаараа би цангинасан гэрчлэл хийж, дараа нь төгс болгуулсан хүн, Бурханыг хайрлах үлгэр жишээ, Бурханы ойр дотнын хүн болж чадах уу? Би бүрэн төгс болгуулж чадах уу? Надад үнэнийг хэлээч!” “Юмс үргэлж хувирч, үргэлж өөрчлөгдөж байдгийг чи мэдэхгүй гэж үү? Одоогоор чи товойлгогч байх үүрэгтээ дуулгавартай байхыг хүсэж байгаа л бол өөрчлөгдөж чадна. Товойлгогч мөн үү, биш үү гэдэг чинь чиний хувь заяатай ямар ч хамаагүй. Амь зан чанартаа өөрчлөлт гаргасан хүн байж чадах уу, үгүй юү гэдэг чинь л гол нь юм.” “Надад хэлээч, Та намайг төгс болгож чадах уу, үгүй юү?” “Чи эцсийг нь хүртэл дагаж, дуулгавартай байж чадах л юм бол чамайг төгс болгож чадна гэдгээ Би баталж байна.” “Би ямар зовлон туулах ёстой вэ?” “Гай тотгор, мөн түүнчлэн үгийн шүүлт, гэсгээлт, ялангуяа үгийн гэсгээлт, энэ нь товойлгогч байх гэсгээлттэй адилхан!” “Бас товойлгогчтой адил гэсгээлт үү? За яах вэ, гай тотгор туулснаар Танаар төгс болгуулж чадах юм бол, найдвар байгаа л бол зүгээр. Ердөө өчүүхэн төдий найдлага байсан ч гэсэн товойлгогч байхаас дээр. ‘Товойлгогч’ хэмээх тэр цол маш муухай сонсогддог. Би товойлгогч байхыг хүсэхгүй байна!” “Товойлгогч байхад юу нь тийм аймаар байгаа юм бэ? Товойлгогчид ч чадвараараа гойд сайн биш гэж үү? Товойлгогчид ерөөл эдлэх үнэ цэнгүй гэж үү? Хэрвээ Би товойлгогч ерөөл эдэлж чадна гэж хэлэх юм бол чи ч гэсэн ерөөл эдэлж чадна. Миний ажлаас болж хүмүүсийн цол өөрчлөгддөг нь үнэн биз дээ? Ердөө нэг цол чамайг ийм их зовоож байна уу? Үнэндээ ийм товойлгогч байх чинь зүй ёсны хэрэг. Чи дагахыг хүсэж байна уу, үгүй юү?” “За яах вэ, Та намайг бүрэн төгс болгож чадах уу, үгүй юү? Таны ерөөлийг эдлэх боломжийг надад олгож чадах уу?” “Чи эцсийг нь хүртэл дагахыг хүсэж байна уу, үгүй юү? Чи өөрийгөө өргөн барихыг хүсэж байна уу?” “Би сайтар бодоод үзье. Товойлгогч ч бас Таны ерөөлийг эдэлж, бүрэн төгс болгуулж чадна. Бүрэн төгс болгуулсныхаа дараа би Таны дотнын хүн болж, Таны хүслийг бүхэлд нь ойлгож, Таны эзэмшдэг зүйлийг эзэмшинэ. Би Таны эдэлдэг зүйлийг эдэлж чадна, бас Таны мэддэг зүйлийг мэднэ… Гай тотгор туулж, төгс болгуулсныхаа дараа би ерөөл эдэлж чадна. Тэгвэл үнэндээ би ямар ерөөл эдлэх юм бэ?” “Чи ямар ерөөл эдлэх талаар бүү санаа зов. Би чамд хэлсэн ч гэсэн чи тэдгээрийг төсөөлж чадахгүй. Сайн товойлгогч байсныхаа дараа чи байлдан

дагуулагдаж, амжилттай товойлгогч байх болно. Энэ бол байлдан дагуулагдсан хүний үлгэр жишээ, загвар юм, гэхдээ мэдээж чи байлдан дагуулагдсаныхаа дараа л үлгэр жишээ, загвар болж чадна.” “Үлгэр жишээ, загвар гэж юу юм бэ?” “Энэ нь бүх Харь үндэстний, өөрөөр хэлбэл, байлдан дагуулагдаагүй хүмүүсийн үлгэр жишээ, загвар юм.” “Тэр нь хэчнээн хүнийг агуулдаг юм бэ?” “Маш олон хүн. Ердөө дөрөв, таван мянган та нар ч биш—бүх дэлхий даяар энэ нэрийг хүлээн зөвшөөрдөг бүх хүн байлдан дагуулагдах ёстой.” “Тэгвэл тав, аравхан хот биш юм байна!” “Энэ талаар одоо бүү санаа зов, хэтэрхий их бүү анхаар. Зүгээр л яг одоо хэрхэн орох ёстой талаараа анхаарлаа төвлөрүүл! Бүрэн төгс болгуулж чадна гэдгийг чинь Би баталж байна.” “Ямар хэмжээнд? Бас би ямар ерөөл эдэлж чадах вэ?” “Чи юунд ингэж их санаа зовно вэ? Бүрэн төгс болгуулна гэдэгт чинь Би баталгаа өгсөн; Би итгэл даадаг гэдгийг чи мартчихав уу?” “Та итгэл даахуйц гэдэг нь үнэн, гэхдээ Таны ярих арга барилын зарим нь үргэлж өөрчлөгдөж байдаг. Өнөөдөр Та бүрэн төгс болгуулж чадна гэдгийг минь батална гэж хэлж байгаа ч маргааш Та, энэ нь лавтай биш гэж хэлж магадгүй. Зарим хүнд Та ‘чам шиг хүн бүрэн төгс болгуулж чадахгүй гэдгийг Би батална’ гэж хэлдэг. Таны үгэнд юу болоод байгааг би мэдэхгүй. Би зүгээр л үүнд итгэж зүрхэлдэггүй.” “Тэгвэл чи өөрийгөө өргөл болгож чадах уу, үгүй юү?” “Юуг өргөл болгоно гэж?” “Өөрийн ирээдүй, өөрийн найдварыг өргөл болгох.” “Тэрийг орхиход амархан! Гол нь ‘товойлгогч’ цол—би үүнийг үнэхээр хүсэхгүй байна. Хэрвээ Та надаас тэр цолыг авчих юм бол би юуг ч хүлээн авч, юуг ч хийж чадна. Эдгээр нь ердөө ялихгүй хэрэг биш гэж үү? Та тэрхүү тодорхойлолтыг авч хаяж чадах уу?” “Тэр амархан, тийм биз дээ? Хэрвээ Би чамд тэр цолыг өгсөн бол бас авч хаяж чадах нь лавтай. Гэхдээ одоо цаг нь биш. Чи ажлын энэ алхмыг туулж гүйцээх ёстой бөгөөд тэр үед л шинэ цол олж авч чадна. Хүн чам шиг байх тусмаа төдий чинээ товойлгогч байх хэрэгтэй. Товойлгогч байхаас чи хэдий чинээ их айна, Би чамайг төдий чинээ их тэгж хаяглана. Чам шиг хүнийг хатуу чанд сахилгажуулж, харьцах ёстой. Хүн тэрслүү байх тусмаа, төдий чинээ үйлчлэл үзүүлэгч байх бөгөөд эцэстээ тэд юу ч олж авахгүй.” “Ингэж их хичээнгүйлэн эрж хайчхаад би яагаад ‘товойлгогч’ хэмээх нэрийг хаяж чадахгүй гэж? Бид энэ бүх жилүүдэд Таныг дагаж, багагүй зовсон. Бид Таны төлөө олон зүйл хийсэн. Салхи бороноор ч явсан; бид залуу насныхаа төгсгөл рүү дөхөж байна. Бид гэрлээгүй, гэр бүлээ ч эхлээгүй, гэрлэсэн ч гэсэн бид мөн л гарч ирдэг. Би дунд сургууль төгстөлөө сургуульд сурсан, гэхдээ Таны ирснийг дуулангуутаа их сургуульд орох боломжоо орхисон. Тэгтэл Та биднийг товойлгогч гэж байна! Бид маш ихийг алдсан! Бид энэ бүхнийг хийсэн боловч одоо ердөө л Таны товойлгогчид болж таарлаа. Энэ нь миний ангийнхан, миний үеийнхэнд намайг юу гэж бодогдуулах вэ? Тэд намайг хараад, албан тушаал, байр суурийн маань талаар асуух үед би яаж ичихгүй тэдэнд хэлж чадах юм бэ? Анх Танд итгэх итгэлээсээ болж би ямар ч төлөөс төлсөн бөгөөд бусад хүмүүс бүгд намайг тэнэг гэж шоолсон. Гэхдээ би дагасаар л байсан бөгөөд итгээгүй бүх хүнд

өөрийгөө харуулж чадах миний өдөр ирэхийг хүлээсэн. Гэтэл харин өнөөдөр Та намайг товойлгогч гэж байна. Хэрвээ Та надад хамгийн дорд цолыг өгсөн бол, намайг хаанчлалын ардуудын нэг байхыг зөвшөөрсөн бол энэ нь зүгээр байх байв! Би Таны шавь, эсвэл Таны итгэлийг хүлээсэн хүн биш байсан ч гэсэн, зүгээр л Таны дагагч байхад миний хувьд зүгээр байх байсан! Энэ бүх жилүүдэд бид Таныг дагаж, гэр бүлээ орхисон бөгөөд өнөөг хүртэл үргэлжлүүлэн эрж хайхад маш хэцүү байсан, харин харуулах зүйл маань ‘товойлгогч’ хэмээх цол л байна! Би Таны төлөө бүхнийг орхисон; газар дэлхийн бүх эд баялгийг орхисон. Урьд нь нэг хүн намайг хань болох боломжтой хүнтэй танилцуулсан. Тэр үнэхээр царайлаг, сайхан хувцасласан байсан; өндөр зиндаатай боловсон хүчний хүү байсан юм. Тухайн үед би түүнийг үнэхээр шохоорхсон. Гэхдээ, Бурхан гарч ирж, ажлаа хийж байгаа, мөн биднийг хаанчлал руу хөтөлж, төгс болгох гэж байгаа бөгөөд цаг алдалгүй бүхнийг орхих шийдвэртэй бай гэж биднээс шаардсаныг сонсмогцоо надад ямар ч шийдэмгий байдал байхгүй байгааг би харсан юм! Тэгээд би өөрийгөө хатуужуулж, тэр боломжоос татгалзсан. Дараа нь тэр манай гэр бүлд хэд хэдэн удаа бэлэг илгээсэн боловч би тэдгээрийг бүр хараа ч үгүй. Тэр үед намайг сэтгэл гонсгор байсан гэж Та бодож байна уу? Тийм сайн зүйл талаар болсон. Би яаж гонсойхгүй байж чадах юм бэ? Би шөнө унтаж ч чадахгүй болтлоо хэдэн өдрийн турш сэтгэл гонсгор байсан боловч эцэст нь больсон. Залбирах бүрд минь: ‘Чи Миний төлөө бүхнийг золиослоход бэлэн үү? Миний төлөө өөрийгөө зарлагадахад бэлэн үү?’ гэж Ариун Сүнс сэтгэлийг минь хөдөлгөдөг. Таны тэдгээр үгийг бодох болгондоо би уйлдаг байсан. Хэчнээн удаа сэтгэл хөдөлж, гуниглан уйлснаа би мэдэхгүй. Жилийн дараа тэр эрэгтэй гэрлэсэн гэдгийг би сонссон. Надад гунигтай байсан гэдгийг хэлэх нь илүүц боловч би Таны төлөө тэрийг бас л орхисон. Миний хоол, хувцас тааруухан гэдгийг дурдахын ч хэрэггүй—би тэрхүү гэрлэлтийг хаясан, энэ бүхнийг хаясан, иймээс Та намайг товойлгогч болгох ёсгүй! Би өөрийгөө Танд өргөн барихын тулд амьдралынхаа хамгийн чухал үйл явдал болох гэрлэлтийг орхисон! Хүний бүх амьдрал нь сайн хань олж, аз жаргалтай гэр бүлтэй байхаас өөр юу ч биш. Би энэ хамгийн сайн зүйлээ тавьж явуулсан, одоо би гар хоосон, орь ганцаараа байна. Та намайг хааш нь явуулах вэ? Би Таныг дагаж эхэлснээсээ хойш л зовсон. Би сайхан амьдралтай байгаагүй. Гэр бүл, ажил мэргэжил, түүнчлэн махан биеийн бүх зугаа цэнгэлийг хаясан бөгөөд бид бүхний гаргасан энэ золиослол Таны ерөөлийг эдлэхэд бас л хангалтгүй гэж үү? Тэгтэл одоо энэ ‘товойлгогч’ гэх зүйл. Бурхан минь, Та үнэхээр дэндлээ! Биднийг хар—энэ дэлхий дээр түшиж тулах юу ч бидэнд алга. Бидний зарим нь хүүхдүүдээ хаясан, зарим нь ажил, хань ижлээ[a] гэх мэтийг хаясан; бид махан биеийн бүх зугаа цэнгэлийг хаясан. Бид өөр юунд найдах ёстой юм бэ? Бид энэ дэлхийд хэрхэн үргэлжлүүлэн амьдрах юм бэ? Бидний гаргасан эдгээр золиос сохор зоосны ч үнэгүй гэж үү? Та тэрийг

[a] Эх бичвэрт “эхнэрээ” гэж байдаг.

огтхон ч харахгүй байна уу? Бидний байр суурь дорд, хэв чанар дутуу дулимаг—бид үүнийг хүлээн зөвшөөрч байгаа боловч Таны биднээр хийлгэхийг хүссэн зүйлийг бид хэзээ ер нь анхаарахгүй байсан юм бэ? Одоо Та биднийг өрөвдөх сэтгэлгүйгээр орхиж, 'товойлгогч' гэх цолоор 'хариу барьж' байгаа юм уу? Бүх золиослол маань 'товойлгогч' хэмээх цолыг л бидэнд авчирсан гэж үү? Эцэст нь хүмүүс надаас Бурханд итгэснээрээ юу олж авсныг асуувал би тэдэнд 'товойлгогч' гэх энэ үгийг харуулж үнэхээр болох уу? Би бол товойлгогч гэж ам нээн хэлж яаж чадах юм бэ? Би эцэг эхдээ тайлбарлаж чадахгүй, мөн хань болох боломжтой байсан хүндээ тайлбарлаж чадахгүй. Би ийм их төлөөс төлсөн, гэтэл хариуд авсан зүйл нь товойлгогч байх! Аах! Надад маш гунигтай санагдаж байна!" (Гуяа цохин, уйлж эхэллээ.) "Хэрвээ Би одоо чамд товойлгогч цолыг өгөхийн оронд Өөрийн ардуудын нэг болгож, удирдамж өгөөд сайн мэдээ түгээлгэхээр явуулна гэж хэлсэн бол, хэрвээ Би чамайг ажиллуулахын тулд байр суурь өгсөн бол чи үүнийг хийж чадах уу? Чи энэ ажлын алхам бүрээс үнэндээ юу олж авсан бэ? Гэтэл чи энд бүр өөрийнхөө түүхээр Намайг хөгжөөж байна—үнэхээр ичгүүр сонжуургүй юм! Чи төлөөс төлсөн гэж хэлсэн боловч юу ч олж аваагүй. Хүнийг олж авах Миний болзол юу болохыг Би чамд хэлэхээ мартсан юм гэж үү? Миний ажил хэний төлөө байдаг вэ? Чи мэдэх үү? Чи энд хуучин гоморхлыг сэдрээж байна! Чи ер нь хүн гэж тооцогдох уу? Туулсан зовлонгоо чи өөрийн хүслээр үүрээгүй гэж үү? Чиний зовлон ерөөл хүртэхийн тулд байгаагүй гэж үү? Чи Миний шаардлагыг хангасан уу? Чи гагцхүү ерөөл олж авахыг л хүсдэг. Чамд ямар ч ичгүүр алга! Чамаас шаардах Миний шаардлага хэзээ ер нь албадмал байдалтай байсан юм бэ? Хэрвээ чи Намайг дагахыг хүсэж байгаа бол бүх зүйл дээр Надад дуулгавартай байх ёстой. Болзол нөхцөлөө тохиролцохоор бүү оролд. Эцсийн эцэст энэ бол зовлонгийн зам гэдгийг Би чамд урьдчилан хэлсэн. Энэ нь хүнд бэрхээр дүүрэн, аятай таатай боломж багатай байдаг. Чи мартчихаа юу? Би үүнийг олон удаа хэлсэн. Хэрвээ чи зовоход бэлэн байгаа бол Намайг дага. Харин зовохыг хүсэхгүй байгаа бол боль. Би чамайг хүчлээгүй—ирэх, явах чинь чөлөөтэй! Гэхдээ, Миний ажил ингэж хийгддэг бөгөөд чиний тэрслүү байдлаас болж Би Өөрийн ажлыг бүхэлд нь хойшлуулж чадахгүй. Чи дуулгавартай байхыг хүсэхгүй байж болох юм, гэхдээ тэгж чадах өөр хүмүүс байгаа. Та нар бүгд цөхрөнгөө барсан хүмүүс! Юунаас ч айдаггүй! Чи Надтай болзол нөхцөл тохиролцож байна—чи үргэлжлүүлэн амьдрахыг хүсэж байна уу, үгүй юү? Чи өөрийнхөө төлөө төлөвлөж, нэр алдар, ашиг хонжооныхоо төлөө тэмцдэг. Миний ажил бүгд та нарын төлөө байдаггүй гэж үү? Чи сохор юм уу? Намайг махбод болохоос өмнө чи Намайг харж чадаагүй бөгөөд чиний хэлсэн эдгээр үгийг тэр үед уучилж болох байсан, гэхдээ одоо Би бие махбодтой болж, та нарын дунд ажиллаж байгаа атал чи бас л харж чадахгүй байна уу? Чи юу ойлгохгүй байгаа юм бэ? Чи хохирол амссан гэж хэлсэн; иймээс цөхрөнгөө барсан хүмүүс та нарыг аврахын тулд Би махбод болж, маш их ажил хийсэн бөгөөд одоо ч чи гомдоллосоор байна—чи Намайг хохирол амссан гэж хэлэхгүй гэж үү? Миний

хийсэн зүйл бүгд та нарын төлөө байгаагүй гэж үү? Би одоогийн биеийн хэмжээнд нь үндэслэн энэ цолыг хүмүүст хэрэглэдэг. Хэрвээ Би чамайг ‘товойлгогч’ гэж нэрлэвэл чи тэр даруй товойлгогч болдог. Үүний адилаар, хэрвээ Би чамайг ‘Бурханы ардуудын нэг’ гэж нэрлэвэл чи тэр даруй тийм болно. Би чамайг юу ч гэж нэрлэсэн, чи тийм л байна. Энэ бүхэн Миний амнаас гардаг хэдхэн үгээр биелдэггүй гэж үү? Миний энэ хэдхэн үг чамд тийм их уур хүрмээр байна уу? За яах вэ тэгвэл, Намайг өршөөгөөрэй! Хэрвээ чи одоо дуулгавартай байхгүй бол эцэстээ хараагдана—тэгвэл чи жаргалтай байх уу? Чи амийн замд анхаарал хандуулдаггүй, харин өөрийн байр суурь, цолонд л төвлөрдөг; чиний амь ямархуу вэ? Асар их төлөөс төлсөн гэдгийг чинь Би үгүйсгэдэггүй, гэхдээ биеийн хэмжээ болон хэрэгжүүлэлтээ хар—одоо ч гэсэн чи болзол нөхцөлөө тохиролцохоор хичээж байна. Шийдэмгий зангаараа олж авсан биеийн хэмжээ чинь энэ үү? Чамд бас ёс жудаг байгаа юу? Чамд мөс чанар байна уу? Би буруу зүйл хийсэн юм гэж үү? Чамд тавих Миний шаардлага алдаатай байсан уу? Тэгвэл энэ юу вэ? Би чамайг хэдэн өдөр товойлгогч болгон ажиллуулах байсан атал чи ингэхийг хүсэхгүй байна. Энэ ямар гээчийн шийдвэр вэ? Та нар бүгд сул дорой, хулчгарууд! Чам шиг хүмүүсийг одоо шийтгэх нь мэдээжийн зүйл!” Намайг ингэж хэлмэгц, тэр эгч нэг ч үг хэлээгүй.

Одоо ийм төрлийн ажлыг туулаад та нар, Бурханы ажлын алхам болон хүмүүсийг өөрчлөх арга барилынх нь талаар ямар нэг зүйл ухаарсан байх ёстой. Ингэх нь өөрчлөлтийн үр дүнд хүрэх цорын ганц зам юм. Эрэл хайгуулд чинь хэтэрхий олон хувийн үзэл, найдлага, ирээдүй байдаг. Одоогийн ажил бол байр суурийн төлөөх хүсэл болон хэрээс хэтэрсэн хүсэлтэй чинь харьцахын төлөө байдаг. Итгэл найдвар, байр суурь, үзэл нь бүгд сатанлаг зан чанарын сонгодог төлөөлөл юм. Сатаны хор хүмүүсийн бодол санааг үргэлж эвддэг ба хүмүүс Сатаны эдгээр уруу таталтаас салж чаддаггүйгээс болж л хүмүүсийн зүрх сэтгэлд эдгээр зүйл оршдог. Тэд нүгэл дунд амьдарч байгаа мөртөө үүнийг нүгэл гэж итгэдэггүй, “Бид Бурханд итгэдэг, иймээс Тэр бидэнд ерөөл хайрлаж, бидний төлөө бүх зүйлийг зохих ёсоор зохицуулах ёстой. Бид Бурханд итгэдэг, иймээс бид бусдаас илүү дээр байх ёстой ба өөр хэнээс ч илүү их байр суурь, ирээдүйтэй байх ёстой. Бид Бурханд итгэдэг болохоор Тэр бидэнд хязгааргүй их ерөөл өгөх ёстой. Эс бөгөөс үүнийг Бурханд итгэх явдал гэж нэрлэхгүй” хэмээн бодсоор байдаг. Олон жилийн турш, амьд үлдэхийн төлөө хүмүүсийн итгэж найддаг үзэл санаа нь тэднийг зальхай, хулчгар, жигшүүртэй болтол зүрх сэтгэлийг нь эвдсээр ирсэн. Тэдэнд сэтгэлийн тэнхээ, шийдвэр дутмаг байгаад зогсохгүй, тэд бас шунахай, биеэ тоосон, дур зоргоороо болсон. Тэдэнд өөрсдийгөө даван гарах шийдвэр огт байдаггүй ба үүнээс гадна эдгээр харанхуйн нөлөөний барьцаас салах эр зориг тэдэнд өчүүхэн ч байдаггүй. Хүмүүсийн бодол болон амьдрал үнэхээр илжирсэн, Бурханд итгэх тухай тэдний үзэл бодол тэвчихийн аргагүй муухай хэвээр байгаа бөгөөд хүмүүс Бурханд итгэх итгэлийн талаарх өөрсдийн үзэл бодлыг ярих үед

сонсож тэвчихийн аргагүй байдаг. Хүмүүс бүгд хулчгар, чадваргүй, жигшүүртэй агаад эмзэгхэн. Тэд харанхуйн хүчинд зэвүүцдэггүй, гэрэл болон үнэнийг хайрладаггүй; харин ч тэдгээрийг хөөн зайлуулахын тулд бүхнийг хийдэг. Та нарын одоогийн бодол болон үзэл санаа яг ийм биш гэж үү? “Нэгэнт Бурханд итгэдэг тул би зүгээр л ерөөлүүдэд дарагдах ёстой, миний байр суурь хэзээ ч алга болохгүй бөгөөд үл итгэгчдийнхээс илүү өндөр байх нь баталгаатай байх ёстой.” Та нар дотроо ийм үзэл санааг ганц, хоёрхон жилийн турш өвөрлөсөөр ирээгүй, харин энэ нь олон жилийн турш тэнд байсан. Та нарын наймаацах сэтгэлгээ хэт их хөгжсөн. Та нар өнөөдөр энэ алхамд хүрсэн хэдий ч байр суурийг одоо ч гэсэн тавьж явуулаагүй, харин нэг л өдөр нэр төр чинь сүйрнэ гэсэн гүн айдастайгаар үргэлж энэ талаар сураглаж, үүнийг өдөр тутам ажиглаж байдаг. Хүмүүс тав тухтай байдалд шунах хүслээ хэзээ ч хойш тавиагүй. Иймээс Би та нарыг одоо ийм маягаар шүүвэл эцэст нь та нар ямар түвшний ойлголттой байх вэ? Хэдийгээр байр суурь чинь өндөр биш боловч ямартай ч Бурханы өргөлтийг эдэлсэн гэж та нар хэлнэ. Дорд зиндаанд төрсөн учраас та нарт байр суурь байхгүй бөгөөд Бурханы өргөлтөөс болж байр суурьтай байгаа—энэ бол та нарт Түүний хайрласан зүйл юм. Өнөөдөр та нар Бурханы сургалтыг, Түүний гэсгээлт болон шүүлтийг биечлэн хүлээн авч чаддаг. Бүр ч илүүтэйгээр энэ нь Түүний өргөлт юм. Бас та нар Түүний ариусгалт болон шатаалтыг биечлэн хүлээн авч чаддаг. Энэ бол Бурханы агуу хайр билээ. Эрин үеүдийн туршид Түүний ариусгалт болон шатаалтыг хүлээн авсан ганц ч хүн байгаагүй, Түүний үгээр төгс болгуулж чадсан нэг ч хүн байгаагүй. Бурхан одоо та нартай нүүр тулан ярилцаж, та нарыг ариусгаж, дотоод тэрслүү занг чинь илчилж байна—энэ нь үнэхээр Түүний өргөлт билээ. Хүмүүс ямар чадвартай вэ? Давидын хөвгүүд байсан ч, эсвэл Моабын үр удам байсан ч, дүгнэн хэлбэл хүмүүс нь сайрхаад байх юмгүй, бүтээгдсэн зүйл юм. Нэгэнт та нар Бурханы бүтээл болохоор бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой. Та нарт тавих өөр шаардлага байхгүй. Та нар ингэж залбирах ёстой: “Өө Бурхан минь! Надад байр суурь байсан ч, үгүй ч одоо би өөрийгөө ойлгож байна. Хэрвээ миний байр суурь өндөр бол Таны өргөлтөөс болж байгаа бөгөөд хэрвээ дорд бол энэ нь Таны тогтоосноос болж байгаа билээ. Бүх зүйл Таны гарт оршдог. Надад ямар ч сонголт, ямар ч гомдол байхгүй. Намайг энэ улсад, энэ хүмүүсийн дунд төрнө гэдгийг Та тогтоосон бөгөөд бүх зүйл Таны тогтоосон зүйл дотор байдаг учраас би зөвхөн Таны ноёрхол дор бүрэн дуулгавартай байх ёстой. Би байр суурь боддоггүй; эцсийн эцэст би бол ердөө бүтээлүүдийн л нэг. Хэрвээ Та намайг ёроолгүй нүхэнд, гал болон хүхэртэй нуурт хийвэл би ердөө л нэг бүтээлээс цаашгүй. Хэрвээ Та намайг ашиглавал би бүтээл. Та намайг төгс болгосон ч би мөн л бүтээл. Та намайг төгс болгохгүй бол би бүтээлээс өөрцгүй учраас Таныг хайрласаар л байх болно. Би бол бүтээлийн Эзэний бүтээсэн өчүүхэн жаахан бүтээл, бүтээгдсэн бүх хүний дундах нэгэн төдий билээ. Та намайг бүтээсэн бөгөөд надад хүссэнээ хийхийн тулд одоо намайг дахин нэгэнтээ Өөрийн гарт байрлуулсан. Бүх зүйл Таны тогтоосон зүйл учраас би Таны

хэрэгсэл, Таны товойлгогч байхад бэлэн байна. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Бүх зүйл, бүх үйл явдал Таны гарт байдаг.” Цаг нь ирэх үед чи байр суурийн талаар бодохоо больж, үүнээс ангижирна. Тэр үед л чи өөртөө итгэлтэйгээр, зоригтойгоор эрж хайж чадах бөгөөд тэр үед л зүрх сэтгэл чинь ямар нэгэн хязгаарлалтаас ангид болж чадна. Эдгээр зүйлээс ангижирмагц хүмүүст өөр санаа зовнил байхаа болино. Яг одоо та нарын олонхын санаа зовнил юу вэ? Та нар үргэлж байр сууринд хязгаарлагддаг бөгөөд байнга хэтийн ирээдүйдээ санаа зовж байдаг. Та нар үргэлж Бурханы айлдваруудын хуудсыг эргүүлэн, хүн төрөлхтний хүрэх газартай холбоотой үгийг уншихыг хүсэж, хэтийн ирээдүй, хүрэх газар чинь ямар байхыг мэдэхийг хүсдэг. “Надад үнэхээр хэтийн ирээдүй байгаа гэж үү? Бурхан тэдгээрийг булаагаад авчихсан уу? Бурхан намайг товойлгогч гэж л хэлсэн; тэгвэл миний хэтийн ирээдүй юу юм бэ?” хэмээн та нар гайхширдаг. Та нарын хувьд хэтийн ирээдүй, хувь заяагаа хойш тавих хэцүү байдаг. Та нар одоо дагалдагчид бөгөөд ажлын энэ үе шатны талаар зарим нэг ойлголт олж авсан. Гэсэн ч та нар байр суурийн төлөөх хүслээ хойш тавиагүй хэвээр байна. Байр суурь чинь өндөр үед сайн эрж хайдаг боловч байр суурь чинь дорд байх үед эрж хайхаа больдог. Байр суурийн ерөөл үргэлж оюун ухаанд чинь байдаг. Яагаад дийлэнх хүмүүс сөрөг байдлаас гарч чаддаггүй юм бэ? Найдваргүй хэтийн ирээдүйгээс болдоггүй гэж үү? Бурханы айлдварууд гармагц та нар байр суурь, ялгамж чанар чинь яг юу болохыг харахаар яардаг. Та нар байр суурь, ялгамж чанарыг эхэнд тавиад үзэгдлийг хоёрдугаарт тавьдаг. Гуравдугаарт та нарын орох ёстой зүйл, харин дөрөвдүгээрт Бурханы одоогийн хүсэл байдаг. Та нарт Бурханы өгсөн “товойлгогч” хэмээх цол өөрчлөгдсөн үү, үгүй юү гэдгийг та нар эхлээд хардаг. Та нар уншсаар уншсаар байдаг бөгөөд “товойлгогч” хэмээх цолыг авч хаясныг харах үедээ баярлаж, Бурханд тасралтгүй талархаж, Түүний агуу хүч чадлыг магтдаг. Гэхдээ та нар товойлгогч хэвээр гэдгээ хальт хармагцаа хямарч, зүрх сэтгэлдээ нэн даруй ямар ч урам зориггүй болдог. Та нар ийм байдлаар хэдий чинээ их эрж хайна, төдий чинээ бага үр дүнд хүрнэ. Байр суурийн төлөөх хүний хүсэл хэдий чинээ их байна, тэдэнтэй төдий чинээ ноцтой харьцах учиртай бөгөөд тэд төдий чинээ их цэвэршүүлэлт туулах ёстой. Тийм хүмүүс үнэ цэнгүй! Тэднээр эдгээр зүйлийг бүрэн хаяулахын тулд харьцаж, шүүх ёстой. Хэрвээ та нар эцсийг нь хүртэл ийм маягаар эрэлхийлбэл ямар ч үр дүнд хүрэхгүй. Амийг эрэлхийлдэггүй хүмүүс өөрчлөгдөж чадахгүй, үнэнээр цангадаггүй хүмүүс үнэнийг олж авч чадахгүй. Чи хувийн өөрчлөлт болон оролтдоо төвлөрдөггүй, харин хэрээс хэтэрсэн хүсэлдээ болон Бурханы төлөөх хайрыг чинь хязгаарлаж, Түүнд ойр очихоос чамайг хязгаарладаг зүйлсэд үргэлж төвлөрдөг. Тэдгээр зүйл чамайг өөрчилж чадах уу? Тэдгээр нь чамайг хаанчлал руу аваачиж чадах уу? Хэрвээ эрэл хайгуулын бай чинь үнэнийг эрж хайх явдал биш бол чи энэ боломжийг ашиглан, амжилтад хүрэхийн тулд дэлхий ертөнцдөө буцаж очсон нь дээр. Ийм маягаар цагаа дэмий үрэх үнэхээр хэрэггүй—юунд өөрийгөө тамлана гэж? Үзэсгэлэнтэй сайхан дэлхий ертөнц дээр

чи элдэв янзын зүйлийг эдэлж чаддаг нь үнэн биз дээ? Мөнгө, сайхан хүүхэн, байр суурь, нэрэлхүү зан, гэр бүл, хүүхдүүд гэх мэт—энэ бүхэн нь чиний эдэлж чадах, дэлхий ертөнцийн хамгийн сайхан зүйлс биш гэж үү? Энэ хавиар эргэлдэж, жаргалтай байж чадах газраа хайх ямар хэрэгтэй юм бэ? Хүний Хүүд толгой хоргодох газар ч байхгүй, иймээс чи яаж амар тайван газартай байж чадах юм бэ? Тэр яаж чамд амар тайван сайхан газар бүтээж өгч чадах юм бэ? Ингэх боломжтой юу? Миний шүүлтээс гадна өнөөдөр чи үнэний талаарх сургаалыг л хүлээн авч чадна. Чи Надаас тав тух олж авч чадахгүй, өдөр шөнөгүй боддог жаргалтай амьдралаа ч олж авч чадахгүй. Би чам дээр энэ дэлхийн эд баялгийг хайрлахгүй. Хэрвээ чи чин сэтгэлээсээ эрэлхийлбэл Би чамд амийн замыг бүхэлд нь өгч, чамайг усандаа буцан орсон загас мэт байлгахад бэлэн байна. Хэрвээ чи чин сэтгэлээсээ эрэлхийлэхгүй бол Би бүгдийг нь буцаан авна. Тав тухтай байдалд шунадаг, гахай нохой шиг хүмүүст Өөрийн амнаас гарах үгийг өгөхийг Би хүсэхгүй байна!

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ХОЁР ДАХЬ АЛХАМ ХЭРХЭН ҮР ДҮНД ХҮРДЭГ ВЭ

Үйлчлэл үзүүлэгчдийн ажил нь байлдан дагуулалтын ажлын эхний алхам байв. Өнөөдөр бол байлдан дагуулалтын ажлын хоёр дахь алхам юм. Байлдан дагуулалтын ажилд яагаад төгс болгуулах тухай бас дурддаг вэ? Энэ нь ирээдүйн суурийг тавихын төлөө байдаг. Өнөөдөр бол байлдан дагуулалтын ажлын эцсийн алхам; их гай зовлон туулах үе дараа нь ирэх бөгөөд энэ нь хүн төрөлхтнийг төгс болгох албан ёсны эхлэлийг тэмдэглэнэ. Одоо гол асуудал нь байлдан дагуулалт боловч өнөө үе нь бас төгс болгох үйл явцын эхний алхмын цаг үе юм. Энэхүү эхний алхам нь хүмүүсийн мэдлэг, дуулгавартай байдлыг төгс болгохыг шаарддаг бөгөөд энэ нь мэдээжийн хэрэг байлдан дагуулалтын ажлын суурийг тавьдаг. Хэрвээ чи төгс болгуулъя гэвэл хожмын гай зовлон дунд бат зогсож, ажлын дараагийн алхмыг түгээхийн тулд бүхнээ зориулж чаддаг байх ёстой; төгс болгуулах гэдэг нь энэ бөгөөд энэ нь бас Бурхан хүмүүсийг бүрэн олж авдаг үе юм. Өнөөдөр бид байлдан дагуулагдах тухай ярьж байгаа нь төгс болгуулах тухай ярихтай адилхан. Гэхдээ өнөөдөр хийгддэг ажил бол ирээдүйд төгс болгуулах суурь юм; төгс болгуулахын тулд хүмүүс саад тотгор туулах ёстой бөгөөд ингэж саад тотгор туулах нь байлдан дагуулагдахад үндэслэх ёстой. Хэрвээ хүмүүст өнөөдрийн суурь байхгүй бол—хэрвээ тэд бүрэн байлдан дагуулагдаагүй бол—ажлын дараагийн алхмын үеэр бат зогсоход хэцүү байх болно. Зүгээр л байлдан дагуулагдах нь эцсийн зорилго биш. Энэ нь харин Сатаны эсрэг Бурханы төлөө гэрчлэл хийх нэг алхам билээ. Төгс болгуулах нь эцсийн зорилго бөгөөд төгс болгуулахгүй бол чи ч бас үл тоогдож магадгүй. Ирээдүйд саад тотгортой тулгарах үед л жинхэнэ биеийн хэмжээ чинь

харагдана; өөрөөр хэлбэл, тэр үед л Бурханыг гэх хайрын чинь цэвэр байдлын түвшин илэрхий болно. Өнөөдөр хүмүүс ингэж хэлдэг: “Бурхан юу ч хийдэг бай хамаагүй, бид дуулгавартай байх ёстой. Иймээс бид Бурханы агуу хүч чадал, Бурханы зан чанарыг харуулж чадах товойлгогч байхад бэлэн байна. Бурхан бидэнд эелдэг хандсан ч, биднийг хараасан ч, эсвэл биднийг шүүсэн ч бай, бид Бурханд талархсан хэвээр байдаг.” Ингэж хэлж байгаа чинь бага зэрэг мэдлэгтэйг чинь л харуулдаг боловч тийм мэдлэгийг бодит байдалд хэрэглэж болох эсэх нь энэхүү мэдлэг жинхэнэ үү, үгүй юү гэдгээс хамаардаг. Хүмүүс өнөөдөр ийм хэрсүү ухаан, мэдлэгтэй байдаг нь байлдан дагуулалтын ажлын үр нөлөө юм. Төгс болгуулж чадах уу, үгүй юү гэдгийг чинь саад тотгортой тулгарах үед л харж болох бөгөөд Бурханыг чин сэтгэлээсээ хайрладаг эсэх чинь тэр үед харагдана. Хэрвээ хайр чинь үнэхээр цэвэр ариун бол чи: “Бид бол товойлгогчид, бид бол Бурханы гар дахь бүтээлүүд” гэж хэлнэ. Сайн мэдээг Харь үндэстнүүдэд түгээх үедээ чи: “Би ердөө л үйлчлэл үзүүлж байна. Бурхан зөвт зан чанараа бидэнд харуулахын тулд бидний доторх завхарсан зан чанарыг ашиглан энэ бүх зүйлийг хэлсэн; хэрвээ Бурхан тийм зүйл хэлээгүй бол бид Бурханыг харж, мэргэн ухааныг нь ойлгож чадахгүй, мөн тийм агуу аврал, тийм агуу ерөөлийг хүлээн авч ч чадахгүй байсан” гэж хэлнэ. Хэрвээ чамд туршлагаар олж авсан ийм мэдлэг үнэхээр байдаг бол тэр нь хангалттай. Гэвч өнөөдөр хэлдэг зүйлийн чинь ихэнх нь ямар ч мэдлэг агуулдаггүй бол “Бид товойлгогчид, үйлчлэл үзүүлэгчид; бид байлдан дагуулагдаж, Бурханы төлөө цангинасан гэрчлэл хийхийг хүсдэг …” гэдэг чинь бөөн хоосон уриа лоозонгоос цаашгүй юм. Зүгээр л ингэж хашхирах нь чамд бодит байдал байдаг гэсэн үг биш, мөн биеийн хэмжээтэй гэдгийг чинь ч энэ нь нотолдоггүй; чи жинхэнэ мэдлэгтэй байх ёстой бөгөөд мэдлэг чинь туршигдах ёстой.

Энэ хугацаанд Бурханы илэрхийлсэн эдгээр айлдварыг чи илүү их уншиж, өөрийнхөө үйлдлийг харьцуулан харах ёстой: Тэр чигтээ товойлгогч мөн гэдэг чинь маргаангүй бодит баримт юм! Өнөөдрийн мэдлэгийн чинь хэмжээ ямар вэ? Чиний санаа, бодол, зан авир, үг, үйл хэрэг—энэ бүх илэрхийлэл нийлээд Бурханы зөвт, ариун байдлыг товойлгогч болдог бус уу? Та нарын илэрхийлэл Бурханы үгээр илчлэгдсэн завхарсан зан чанарын илрэл бус уу? Бодол, санаа, сэдэл, чамд илэрдэг завхрал чинь Бурханы зөвт зан чанарыг, түүнчлэн Түүний ариун байдлыг харуулдаг. Бурхан ч бас бузар газар төрсөн, гэхдээ бузраар сэвтээгүй хэвээр байдаг. Тэрээр чам шиг л энэ бузар дэлхийд амьдардаг боловч эрүүл ухаан, ухамсарлах чадвартай бөгөөд бузрыг үзэн яддаг. Чи өөрийнхөө үг, үйл хэргээс ямар нэгэн бузар юм олж илрүүлж ч чаддаггүй байж магадгүй, харин Тэр чаддаг бөгөөд чамд тэдгээрийг зааж үзүүлдэг. Чиний тэр хуучин зүйлс—боловсрол, хэрсүү ухаан, эрүүл ухаан дулимаг байдал, амьдралын хоцрогдмол хэв маяг—өнөөдрийн илчлэлээр ил болчихсон; Бурхан ажиллахын тулд газар дээр ирснээр л хүмүүс Түүний ариун байдал, зөвт зан чанарыг хардаг. Тэрээр чамайг шүүж, гэсгээж, чамд ойлгуулдаг; заримдаа чөтгөрлөг уг чанар чинь харагддаг бөгөөд Тэр үүнийг чамд

зааж үзүүлдэг. Тэрээр хүний мөн чанарыг арван хуруу шигээ мэддэг. Мөн та нарын дунд амьдарч, адилхан хоол идэж, адилхан орчинд амьдардаг—тэгсэн ч гэсэн Тэр илүү ихийг мэддэг; Тэр чамайг илчилж, хүмүүсийн завхарсан мөн чанарыг нэвт харж чаддаг. Хүний амьдралын гүн ухаан болон шударга бус, ов мэхтэй байдлыг хамгийн их үзэн яддаг. Ялангуяа хүмүүсийн махан биеийн харилцааг зэвүүцдэг. Тэрээр хүний амьдралын гүн ухааныг мэддэггүй байж болох ч хүмүүсийн илчилдэг завхарсан зан чанарыг тодорхой харж, ил болгож чадна. Тэгээд үг хэлж, эдгээр зүйлээр дамжуулан хүнд зааж сургахын тулд ажилладаг ба хүмүүсийг шүүх, мөн Өөрийн зөвт, ариун зан чанарыг харуулахын тулд эдгээр зүйлийг ашигладаг. Тийнхүү хүмүүс Түүний ажлыг товойлгогчид болдог. Бие махбодтой болсон Бурхан л хүний завхарсан зан чанар болон Сатаны бүх үзэшгүй муухай нүүр царайг ил болгож чадна. Тэр чамайг шийтгэдэггүй, харин зөвт, ариун байдлынхаа товойлгогч болгон ашигладаг төдий боловч чи хэтэрхий бузар учраас ичиж зовон, нүүр хийх газаргүй болдог. Тэрээр хүнд илэрдэг тэр зүйлсийг ашиглан ярьдаг бөгөөд эдгээр зүйлийг ил болгох үед л хүмүүс Бурхан хэчнээн ариун болохыг мэдэж авдаг. Хүмүүст байгаа өчүүхэн төдий хольцыг ч, зүрх сэтгэлд нь оршдог бузар бодлыг ч Тэр анзааралгүй өнгөрдөггүй; хүмүүсийн үг, үйлдэл Өөрийнх нь хүсэлтэй нийцэхгүй бол Тэр өршөөдөггүй. Түүний үгэнд хүмүүсийн, эсвэл өөр юуны ч бузрыг багтаах зай үгүй—эдгээрийг бүгдийг нь ил болгох ёстой. Тэр үед л чи Бурхан үнэхээр хүнтэй адилгүйг хардаг. Хүмүүст өчүүхэн төдий л бузар байвал Тэр тэднийг туйлын их жигшдэг. Заримдаа хүмүүс ойлгож чадалгүй, “Бурхан минь, Та яагаад ингэж их уурладаг юм бэ? Та яагаад хүний сул талыг анхаарч үздэггүй юм бэ? Яагаад хүмүүсийг жаахан ч болов уучилдаггүй юм бэ? Яагаад хүнд ийм хайхрамжгүй ханддаг юм бэ? Мэдээж, хүмүүс хэр их завхарсныг Та мэднэ, тэгвэл тэдэнд яагаад ингэж хандсаар байдаг юм бэ?” гэж хэлэх үе ч байдаг. Бурхан нүглийг үзэн яддаг, үүнд зэвүүцдэг бөгөөд ялангуяа чамд дуулгаваргүй байдлын ямар нэг ул мөр байвал зэвүүцдэг. Чамайг тэрслүү зан чанар илчлэх үед Тэр үүнийг хараад, ихэд зэвүүцдэг—ер бусын их зэвүүцдэг. Эдгээр зүйлээр дамжуулан Түүний зан чанар болон Бурхан юу болох нь харагддаг. Хэдийгээр Тэр хүнтэй адилхан хоол идэж, адилхан хувцас өмсөж, адилхан зүйл эдэлж, хүмүүстэй хамт амьдарч, оршин суудаг боловч хүнтэй адилгүй гэдгийг чи өөрийгөө харьцуулж үзэхдээ ойлгодог. Энэ нь товойлгогчийн ач холбогдол биш гэж үү? Хүний эдгээр зүйлээр дамжуулан Бурханы хүч чадал харагддаг; харанхуй нь гэрлийн эрхэм нандин оршин тогтнолыг тодруулдаг.

Мэдээж, Бурхан та нарыг товойлгогч болгохын төлөө л товойлгогч болгодоггүй. Харин ч энэ ажил үр дүнгээ өгөх үед л хүний тэрслүү байдал бол Бурханы зөвт зан чанарыг товойлгогч гэдэг нь илэрхий болдог бөгөөд та нар товойлгогч учраас л Бурханы зөвт зан чанарын төрөлхийн илэрхийллийг мэдэх боломжтой байдаг. Та нар тэрслүү байдлынхаа улмаас шүүгдэж, гэсгээгддэг боловч тэрслүү байдал чинь та нарыг товойлгогч болгодог бөгөөд тэрслүү байдлаасаа болж та нар Бурханы

хайрладаг агуу нигүүлслийг хүлээн авдаг. Тэрслүү байдал чинь Бурханы бүхнийг чадагч байдал болон мэргэн ухааныг товойлгогч болдог бөгөөд тэрслүү байдлаасаа болоод та нар ийм агуу аврал, ерөөлийг олж авсан. Та нар Надаар ахин дахин шүүгдсэн хэдий ч урьд нь хүний хэзээ ч хүртэж байгаагүй үлэмж их авралыг хүртсэн. Энэ ажил та нарын хувьд туйлын их ач холбогдолтой. “Товойлгогч” байх нь та нарын хувьд бас туйлын үнэ цэнтэй: Товойлгогч учраас та нар авралын нигүүлслийг хүртсэн, иймээс тийм товойлгогч дээд зэргийн үнэ цэнтэй бус уу? Дээд зэргийн ач холбогдолтой бус уу? Та нар Бурхантай адилхан нэг ертөнцөд, адилхан бузар газарт амьдардаг учраас товойлгогч мөн бөгөөд хамгийн агуу авралыг хүртдэг. Хэрвээ Бурхан махбод болоогүй бол хэн та нарт өршөөнгүй хандаж, дорд хүмүүс та нарыг хэн харж хандах юм бэ? Хэн та нарыг анхаарах юм бэ? Хэрвээ Бурхан та нарын дунд ажиллах гээд махбод болоогүй бол та нараас өмнө хүмүүс ер хүртэж байгаагүй энэ авралыг хэзээ та нар хүртэх байсан бэ? Хэрвээ Би та нарыг халамжилж, нүглийг чинь шүүхийн тулд махбод болоогүй бол та нар аль эрт Үхэгсдийн оронд уначих байсан бус уу? Хэрвээ Би махбод болж, та нарын дунд Өөрийгөө даруухан болгоогүй бол та нар яаж Бурханы зөвт зан чанарыг товойлгогч байх эрхтэй байж чадах юм бэ? Та нарт хамгийн агуу аврал хүртэх боломж олгохын тулд Би хүний төрхтэй болж, та нарын дунд ирсэн учраас л та нар товойлгогч болдог бус уу? Намайг махбод болсон учраас л та нар энэ авралыг хүртдэг бус уу? Бурхан та нартай амьдрахын тулд махбод болоогүй бол хүний тамд та нар гахай нохойноос дор амьдарч байгаагаа бас л олж мэдэх байсан уу? Махбод дахь Миний ажлын товойлгогчид учраас та нар гэсгээгдэж, шүүгдсэн бус уу? Товойлгогчийн ажлаас илүү тохиромжтой ажил гэж та нарт үгүй, яагаад гэвэл, товойлгогч учраас л та нар шүүлтийн дунд аврагддаг. Товойлгогч болж үйлдэх шалгуурыг хангах нь амьдралын чинь ерөөл гэж та нарт санагдахгүй байна уу? Та нар ердөө л товойлгогчийн ажил хийдэг мөртөө өмнө нь хэзээ ч хүртэж байгаагүй, бүр төсөөлж ч байгаагүй тийм аврал хүртдэг. Өнөөдөр, товойлгогч байх нь та нарын үүрэг бөгөөд ирээдүйд мөнхийн ерөөл эдлэх нь зүй ёсны шагнал чинь юм. Та нарын олж авдаг аврал бол өнөө үеийн цаг зуурын хэрсүү ухаан юм уу түрхэн зуурын мэдлэг биш, харин илүү агуу ерөөл буюу амийн мөнхийн үргэлжлэл билээ. Хэдийгээр Би та нарыг байлдан дагуулахын тулд “товойлгогч”-ийг ашигласан ч та нарыг олж авахын тулд энэхүү аврал, ерөөлийг өгдөг гэдгийг та нар мэдэх ёстой; энэ нь байлдан дагуулалтын төлөө байдаг боловч бас Би та нарыг илүү сайн аврахын төлөө байдаг. “Товойлгогч” гэдэг нь бодит баримт боловч тэрслүү байдлаасаа болж та нар товойлгогч болдог бөгөөд үүнээс болж хэн ч, хэзээ ч олж авч байгаагүй авралыг хүртсэн. Өнөөдөр та нарт харуулж, сонсгодог; маргааш та нар хүлээн авна, түүнээс гадна асар их ерөөгдөнө. Тиймээс товойлгогчид хамгийн их үнэ цэнтэй биш гэж үү? Тэрслүү зан чанарыг чинь товойлгогч болгосноор өнөөдрийн байлдан дагуулалтын ажил үр нөлөөтэй болдог. Өөрөөр хэлбэл, гэсгээлт, шүүлтийн хоёр дахь тохиолдлын оргил үе нь бузар,

тэрслүү байдлыг чинь товойлгогч болгон ашиглаж, Бурханы зөвт зан чанарыг та нарт харуулах явдал юм. Шүүлт, гэсгээлтийн хоёр дахь тохиолдлын үеэр та нар дахин нэгэнтээ дуулгавартай болоход Бурханы зөвт зан чанар та нарт тэр чигтээ ил тод харагддаг. Өөрөөр хэлбэл, байлдан дагуулалтын ажлыг хүлээн зөвшөөрөх чинь төгсгөлдөө очих үед энэ нь бас товойлгогчийн үүргийг биелүүлж дуусах үе чинь байдаг. Та нарт хаяг шошго өгөх нь Миний санаа зорилго биш. Харин ч Би байлдан дагуулалтын ажлын эхний тохиолдлыг гүйцэтгэхийн тулд үйлчлэл үзүүлэгчийн үүргийг чинь ашиглан Бурханы зөвт, халдашгүй зан чанарыг харуулж байгаа юм. Байлдан дагуулалтын ажлын хоёр дахь тохиолдлын үр нөлөө нь та нарын эрс ялгаатай байдлаар, мөн товойлгогч болон үйлдэх тэрслүү байдлаар чинь дамжин гарч, эхний тохиолдлоор бүрэн илчлэгдээгүй Бурханы зөвт зан чанарыг та нарт бүрэн илчилж, мөн ажлынх нь мэргэн ухаан, гайхамшиг, цэвэр ариун байдлаас бүрддэг Бурханы зөвт зан чанарыг бүхэлд нь, Тэр юу болохыг бүгдийг нь та нарт үзүүлдэг. Ийм ажлын үр нөлөөнд өөр өөр цаг үеийн байлдан дагуулалт, шүүлтийн өөр өөр түвшнээр дамжуулан хүрдэг. Шүүлт оргилдоо хүрэх нь ойртох тусам хүмүүсийн тэрслүү зан чанарыг төдий чинээ их илчилдэг бөгөөд байлдан дагуулалт төдий чинээ үр нөлөөтэй байдаг. Байлдан дагуулалтын энэ ажлын үеэр Бурханы зөвт зан чанар бүхэлдээ ил болдог. Байлдан дагуулалтын ажлыг хоёр алхамд хуваадаг бөгөөд өөр өөр үе шат, түвшинтэй байдаг тул мэдээж хүрдэг үр дүн нь ч бас өөр өөр байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн дуулгавартай байдлын хэмжээ улам ч гүн гүнзгий болдог. Үүний дараа л хүмүүсийг төгс болгуулах зөв зам руу бүрэн аваачиж болно; байлдан дагуулалтын бүх ажил гүйцэлдсэний дараа л (шүүлтийн хоёр дахь тохиолдол эцсийн үр дүндээ хүрсэн байх үед) хүмүүс шүүгдэхээ болиод амийг туулах зөв замд ордог. Яагаад гэвэл, шүүлт нь байлдан дагуулалтыг төлөөлдөг бөгөөд байлдан дагуулалт нь шүүлт, гэсгээлтийн хэлбэртэй байдаг.

Бурхан хамгийн хоцрогдмол, хамгийн бузар газарт махбод болсон бөгөөд ийм маягаар л Өөрийн ариун, зөвт зан чанарыг бүхэлд нь тодорхой харуулж чаддаг. Түүний зөвт зан чанар юугаар дамжин харагддаг вэ? Тэрээр хүний нүглийг шүүх үед, Сатаныг шүүх үед, нүглийг зэвүүцэх үед, Өөрийг нь эсэргүүцэж, Өөрийнх нь эсрэг тэрсэлдэг дайснуудаа үзэн ядах үед энэ нь харагддаг. Өнөөдөр Миний хэлдэг үг хүний нүглийг шүүхийн төлөө, хүний зөв шударга бус байдлыг шүүхийн төлөө, хүний дуулгаваргүй байдлыг хараахын төлөө байдаг. Хүний шударга бус, ов мэхтэй байдал, хүний үг, үйлдэл—Бурханы хүсэлтэй нийцдэггүй бүхэн шүүлтэд өртөх ёстой бөгөөд хүний бүхий л дуулгаваргүй байдал нүгэл гэж буруутгагддаг. Бурханы үг шүүлтийн зарчмыг тойрон эргэлддэг; Тэрээр зөвт зан чанараа харуулахын тулд хүний зөв шударга бус байдлыг шүүж, хүний тэрслүү байдлыг харааж, хүний үзэшгүй муухай нүүр царайг илчилдэг. Ариун байдал бол Түүний зөвт зан чанарын төлөөлөл бөгөөд үнэн хэрэгтээ Бурханы ариун байдал нь Түүний зөвт зан чанар билээ. Та нарын завхарсан зан чанар өнөөдрийн үгийн цаад шалтгаан юм—Би тэдгээрийг ашиглан үг хэлж, шүүж, байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэдэг.

Ганцхан энэ л жинхэнэ ажил, ганцхан энэ л Бурханы ариун байдлыг бүрэн тодруулдаг. Хэрвээ чамд завхарсан зан чанарын ямар ч ул мөр байдаггүй бол Бурхан чамайг шүүхгүй, зөвт зан чанараа ч чамд харуулахгүй. Чи завхарсан зан чанартай тул Бурхан чамайг хэлтрүүлэхгүй бөгөөд үүгээр дамжуулан Түүний ариун байдал харагддаг. Хүний бузар, тэрслүү байдал хэтэрхий их байгааг харсан мөртөө үг хэлж, чамайг шүүхгүй бол, мөн зөв шударга бус байдлын чинь төлөө чамайг гэсгээхгүй бол Тэр нүглийг үзэн ядахгүй байгаа учраас энэ нь Түүнийг Бурхан биш гэдгийг батлах байлаа; Тэр яг хүнтэй л адил бузар байх байв. Өнөөдөр бузраас чинь болж Би чамайг шүүдэг, завхрал болон тэрслүү байдлаас чинь болж Би чамайг гэсгээдэг. Би та нарт хүч чадлаа гайхуулж, эсвэл та нарыг зориуд дарангуйлж байгаа юм биш; харин энэхүү бузар газарт төрж, бузраар маш их бохирдсон та нараас болж Би эдгээр зүйлийг хийдэг. Та нар бохир газарт амьдардаг гахайтай адилаар ёс жудаг, хүн чанараа алдчихсан. Бузар булай, завхралаасаа болж та нар шүүгддэг бөгөөд Би уур хилэнгээ та нар дээр буулгадаг. Яг эдгээр үгийн шүүлтээс болж л та нар Бурхан бол зөвт Бурхан, Бурхан бол ариун Бурхан гэдгийг харж чадсан; Өөрийн ариун, зөвт байдлаас л болж Тэр та нарыг шүүж, уур хилэнгээ та нар дээр буулгадаг; Тэрээр хүн төрөлхтний тэрслүү байдлыг хардаг учраас л зөвт зан чанараа илчилдэг. Хүн төрөлхтний бузар булай болон завхрал Түүний ариун байдлыг ил болгодог. Тэр бол өө сэвгүй, ариун атлаа бузар газарт амьдардаг Бурхан Өөрөө мөн гэдгийг энэ нь хангалттай харуулдаг. Хэрвээ хүн бусадтай хамт намаг балчигт тэлчилдэг, ямар ч ариун гэх юмгүй, ямар ч зөвт зан чанаргүй бол хүний увайгүй авирыг шүүх эрхгүй, хүнийг шүүх шүүлт гүйцэтгэхэд ч тохирохгүй. Бие биетэйгээ эн тэнцүүхэн бузар хүмүүс яаж өөртэйгөө адилхан хүмүүсийг шүүх эрхтэй байж чадах юм бэ? Ариун Бурхан Өөрөө л бузар хүн төрөлхтнийг бүгдийг нь шүүж чаддаг. Хүн яаж хүний нүглийг шүүж чадах юм бэ? Хүн яаж хүний нүглийг харж чадах юм бэ, бас хүн яаж эдгээр нүглийг яллах эрхтэй байж чадах юм бэ? Хэрвээ Бурхан хүний нүглийг шүүх шаардлагыг хангадаггүй байсан бол зөвт Бурхан Өөрөө байж яаж чадах юм бэ? Хүмүүс завхарсан зан чанараа илчилдэг учраас Бурхан тэднийг шүүхийн тулд үг хэлдэг, тэр үед л хүмүүс Тэр бол ариун Бурхан гэдгийг харж чадна. Бурхан хүний нүглийг илчлэнгээ нүглийнх нь төлөө хүнийг шүүж, гэсгээж байх зуур нэг ч хүн, нэг ч юм энэхүү шүүлтээс зугтаж чадахгүй; бузар бүхнийг Тэр шүүдэг, ийм маягаар л Түүний зан чанар зөвт гэдэг нь харагддаг. Эс бөгөөс, та нарыг нэрэн дээрээ ч, нидэр дээрээ ч товойлгогчид гэж яаж хэлж болох юм бэ?

Израильд хийгдсэн ажил болон өнөөдрийн ажлын хооронд асар их ялгаа бий. Ехова израильчуудын амьдралыг залж чиглүүлсэн бөгөөд тийм ч их гэсгээлт, шүүлт байгаагүй, учир нь тухайн үед хүмүүс дэлхий ертөнцийг дэндүү бага ойлгодог, цөөн хэдэн завхарсан зан чанартай байсан юм. Тэр үед израильчууд Еховад үг дуугүй захирагддаг байв. Түүнийг тахилын ширээ барь гэж хэлэхэд тэд даруйхан тахилын ширээ барьсан; тахилчийн хувцас өмс гэхэд тэд дуулгавартай

дагасан. Тухайн үед Ехова хонин сүргээ хариулж байгаа хоньчин шиг байж, хоньд нь хоньчны удирдамжийг дагаж, бэлчээрт өвс ногоо идэж байгаа мэт байсан; Ехова тэдний амьдралыг залж чиглүүлэн, яаж идэх, хувцаслах, аж төрөх, аялахад нь тэднийг хөтөлж байсан юм. Тэр үе нь Бурханы зан чанарыг ил болгох цаг үе байгаагүй, учир нь тухайн үеийн хүн төрөлхтөн дөнгөж мэндэлсэн байсан; тэрслүү, эсэргүү хүмүүс цөөхөн, хүн төрөлхтний дунд тийм ч их бузар бохир байгаагүй тул хүмүүс Бурханы зан чанарыг товойлгогч болон ажиллаж чадахгүй байлаа. Бузрын газрын хүмүүсээр дамжуулан Бурханы ариун байдал харагддаг; өнөөдөр Тэрээр бузрын газрын энэ хүмүүсээс үзэгддэг бузрыг ашигладаг, мөн шүүдэг, ингэснээр Тэр юу болох нь шүүлтийн дунд илчлэгддэг. Тэр яагаад шүүдэг вэ? Нүглийг үзэн яддаг учраас Тэр шүүлтийн үг хэлж чаддаг; хүн төрөлхтний тэрслүү байдлыг зэвүүцдэггүй байсан бол Тэр яаж тэгтлээ их уурлаж чадах юм бэ? Түүний дотор ямар ч зэвүүцэл, дургүйцэл байгаагүй бол, мөн Тэрээр хүмүүсийн тэрслүү байдлыг тоогоогүй бол хүнтэй адил бузар гэдгийг энэ нь нотлох байлаа. Тэрээр бузрыг үзэн яддаг учраас хүнийг шүүж, гэсгээж чаддаг бөгөөд Түүний үзэн яддаг зүйл Өөрт нь байдаггүй. Хэрвээ Түүнд бас эсэргүүцэл, тэрслүү байдал байсан бол эсэргүү, тэрслүү хүмүүсийг Тэр үзэн ядахгүй байх байлаа. Эцсийн өдрүүдийн ажлыг Израильд гүйцэтгэсэн бол ямар ч утга учиргүй байх байв. Эцсийн өдрүүдийн ажил яагаад хамгийн харанхуй, хамгийн хоцрогдмол газар болох Хятадад хийгдэж байгаа юм бэ? Бурханы ариун, зөвт байдлыг харуулахын тулд. Товчхондоо, уг газар харанхуй байх тусам Бурханы ариун байдал төдий чинээ тодорхой харагдаж чадна. Үнэн хэрэгтээ энэ бүхэн нь Бурханы ажлын төлөө байдаг. Бурхан та нарын дунд зогсохоор тэнгэрээс буун ирж, бузар муухай, тэрслүү байдлаар чинь илрэн харагдсан гэдгийг та нар өнөөдөр л ухаарч, Бурханыг одоо л мэдэж байна. Энэ нь хамгийн агуу өргөлт бус уу? Үнэн хэрэгтээ, та нар бол Хятад дахь сонгогдсон бүлэг хүмүүс юм. Та нар сонгогдож, Бурханы нигүүлслийг эдэлсэн учраас, мөн тийм агуу нигүүлслийг эдлэхэд тохирохгүй учраас энэ бүхэн нь та нарыг дээд зэргээр өргөсөн хэрэг гэдгийг энэ нь нотолдог. Бурхан та нарт харагдаж, ариун зан чанараа бүхэлд нь та нарт үзүүлж, бүгдийг нь та нарт өгсөн бөгөөд эдэлж болох бүх ерөөлийг та нарт эдлүүлсэн. Та нар Бурханы зөвт зан чанарыг амтлаад зогсохгүй, мөн түүнчлэн, Бурханы аврал, Бурханы золин аврал, Бурханы хэмжээлшгүй, хязгааргүй хайрыг амссан. Хамгийн бузар хүмүүс та нар тийм агуу нигүүлсэл эдэлсэн—та нар ерөөгдсөн бус уу? Энэ нь Бурхан та нарыг өргөж байгаа хэрэг бус уу? Хүмүүс та нар хамгийн дорд байр суурьтай; та нар төрөлхөөсөө тийм агуу ерөөлийг эдлэхэд тохирохгүй боловч Бурхан тусгайлан үзэж, та нарыг өргөсөн. Чи ичихгүй байна уу? Хэрвээ чи үүргээ биелүүлж чадахгүй бол эцэст нь өөрөөсөө ичиж, өөрийгөө шийтгэнэ. Өнөөдөр чамайг сахилгажуулаа ч үгүй, шийтгээ ч үгүй; махан бие чинь эсэн мэнд, эрүүл саруул байгаа—гэвч эцэстээ эдгээр үг чамайг ичээнэ. Өнөөг хүртэл Би хэн нэгнийг хараахан ил тод гэсгээгээгүй; Миний үг хатуу байж болох ч Би хүмүүст хэрхэн ханддаг вэ? Би тэднийг тайтгаруулж, тэднийг ятгаж, тэдэнд

сануулдаг. Би та нарыг аврахын тулд л үүнийг хийдэг. Та нар Миний хүслийг үнэхээр ойлгодоггүй гэж үү? Та нар Миний хэлдэг зүйлийг ойлгож, үүгээр зоригжих ёстой. Одоо л үүнийг ойлгодог олон хүн бий. Энэ нь товойлгогч байхын ерөөл биш гэж үү? Товойлгогч байх нь хамгийн ерөөлтэй зүйл биш гэж үү? Эцэст нь сайн мэдээ түгээхээр явах үедээ та нар “Бид бол жирийн л нэг товойлгогчид” гэж хэлнэ. Тэд: “Жирийн л нэг товойлгогч гэдэг чинь юу гэсэн үг юм бэ?” гэж асууна. Тэгэхэд нь чи: “Бид бол Бурханы ажил болон Түүний агуу хүч чадлыг товойлгогч. Бидний тэрслүү байдлаас болж Бурханы зөвт зан чанар бүхэлдээ ил гардаг; бид бол Бурханы эцсийн өдрүүдийн ажлын хүчин зүтгэгчид, Түүний ажлын хавсралтууд, бас багаж хэрэгсэл нь” гэж хариулна. Үүнийг сонсоод тэдний сонирхол төрнө. Дараа нь чи: “Бурхан бүх орчлон ертөнцийн ажлыг гүйцэлдүүлж, бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулахын үлгэр, загвар нь бид юм. Бид ариун ч бай, бузар ч бай, ерөнхийдөө, бас л та нараас илүү ерөөгдсөн, учир нь бид Бурханыг харсан, мөн биднийг байлдан дагуулах боломжоор нь дамжуулан Бурханы агуу хүч чадал үзэгддэг; бид бузар, завхарсан учраас л Түүний зөвт зан чанар тодордог. Та нар Бурханы эцсийн өдрүүдийн ажлын талаар ингэж гэрчилж чадах уу? Та нар шаардлага хангахгүй! Энэ бол Бурхан биднийг өргөсөн хэрэг! Бид биеэ тоосон биш байж болох ч Бурханыг бардмаар магтаж чадна, учир нь тийм агуу амлалтыг хэн ч өвлөж чадахгүй, тийм агуу ерөөлийг хэн ч эдэлж чадахгүй. Ийм их бузар бид Бурханы удирдлагын үеэр товойлгогч болон ажиллаж чадах болсондоо маш их баяртай байна” гэж хэлнэ. Тэгээд тэднийг “Үлгэр, загвар гэж юу юм бэ?” хэмээн асуухад нь чи: “Бид бол хамгийн тэрслүү, бузар хүмүүс; биднийг Сатан хамгийн гүн гүнзгий завхруулсан ба бид хамгийн хоцрогдмол, хамгийн дорд махан биетэй хүмүүс. Бид бол Сатаны ашиглаж ирсэн хүмүүсийн сонгодог жишээ. Өнөөдөр бид хүн төрөлхтний дундаас хамгийн түрүүнд байлдан дагуулагдахаар Бурханаар сонгогдсон, Бурханы зөвт зан чанарыг харж, Түүний амлалтыг өвлөсөн; илүү олон хүнийг байлдан дагуулахын тулд биднийг ашиглаж байгаа, тиймээс бид бол хүн төрөлхтний дундаас байлдан дагуулагддаг хүмүүсийн үлгэр, загвар юм” гэж хэлнэ. Эдгээр үгээс илүү дээр гэрчлэл гэж үгүй бөгөөд энэ бол чиний хамгийн сайн туршлага билээ.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН 2

Та нар хаад мэт хаанчлахыг хичээдэг байсан бөгөөд өнөөдөр ч үүнийгээ хараахан орхиогүй; хаан болон хаанчилж, тэнгэрийг өргөж, газрыг тулахыг хүссээр байдаг. Одоо энэ асуултыг бодоод үз: Чамд тийм чадвар байгаа юу? Чи ямар ч эрүүл ухаангүй байгаа бус уу? Та нарын эрж хайж, анхаарлаа хандуулдаг зүйл бодитой юу? Та нарт хэвийн хүн чанар ч байдаггүй—энэ нь өрөвдмөөр биш гэж үү? Тиймээс өнөөдөр Би зөвхөн байлдан дагуулагдах, гэрчлэл хийх, хэв чанараа

сайжруулах, төгс болгуулах замд орох тухай л яриад, өөр юуны ч талаар ярьдаггүй. Зарим хүн хольцгүй үнэнээс залхдаг ба хэвийн хүн чанар болон хүмүүсийн хэв чанарыг сайжруулах тухай энэ бүх яриаг харах үедээ дурамжхан байдаг. Үнэнийг хайрладаггүй хүмүүсийг төгс болгох амаргүй. Та нар өнөөдөр орж, Бурханы хүслийн дагуу алхам алхмаар үйлдэж байгаа цагт таягдан хаягдаж болно гэж үү? Бурхан Хятадын эх газарт ийм их далайцтай, маш их ажил хийж, маш олон үг хэлснийхээ дараа замын хагасаас больж чадна гэж үү? Тэрээр хүмүүсийг ёроолгүй нүх рүү доош хөтөлж чадна гэж үү? Өнөөдөр, гол зүйл нь та нар хүний мөн чанарыг мэдэж, юу руу орох ёстойгоо мэдэх ёстой; мөн амийн оролт, зан чанарын өөрчлөлт, хэрхэн үнэхээр байлдан дагуулагдах, хэрхэн Бурханд бүрэн дуулгавартай байж, Бурханд сүүлчийн гэрчлэл хийж, үхэлд хүртэл дуулгавартай байх талаар ярих ёстой. Чи эдгээр зүйл дээр анхаарлаа төвлөрүүлж, бодит бус, эсвэл чухал бус зүйлсийг юун түрүүнд хойш тавьж, үл тоомсорлох ёстой. Өнөөдөр чи хэрхэн байлдан дагуулагдах талаар болон байлдан дагуулагдсаныхаа дараа хүмүүс биеэ хэрхэн авч явах талаар мэддэг байх ёстой. Чи өөрийгөө байлдан дагуулагдсан гэж хэлэх байх, гэвч чи үхэлд хүртэл дуулгавартай байж чадах уу? Ямар нэгэн хэтийн ирээдүй байгаа эсэхээс үл хамааран чи эцсээ хүртэл дагах чадвартай байх ёстой бөгөөд орчин ямар ч байлаа гэсэн, Бурханд итгэх итгэлээ алдах ёсгүй. Эцэстээ чи гэрчлэлийн хоёр талыг биелүүлэх ёстой: Иовын гэрчлэл—үхэлд хүртэл дуулгавартай байх ба Петрийн гэрчлэл—Бурханыг гэх дээд зэргийн хайр. Нэг талаар чи Иов шиг байх ёстой: Тэр бүх материаллаг хөрөнгөө алдаж, махан биеийн өвчин шаналалд нэрвэгдсэн атлаа Еховагийн нэрийг хаяагүй. Энэ нь Иовын гэрчлэл байв. Петр үхэлд хүртэл Бурханыг хайрлаж чадсан. Тэрээр загалмайд цовдлогдож, үхэлтэйгээ нүүр тулах үедээ Бурханыг хайрласаар байсан; тэр хэтийн ирээдүйгээ бодоогүй, эсвэл сайхан найдвар, хэрээс хэтэрсэн бодлоо эрэлхийлээгүй бөгөөд зөвхөн Бурханыг хайрлаж, Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагахаар зорьсон билээ. Энэ бол чиний хүрэх ёстой стандарт, ингэвэл чамайг гэрчлэлтэй гэж үзэх бөгөөд чи байлдан дагуулагдсаныхаа дараа төгс болгуулсан нэгэн болно. Өнөөдөр хүмүүс мөн чанар, байр сууриа үнэхээр мэддэг байсан бол хэтийн ирээдүй, эсвэл итгэл найдварыг эрж хайсаар байх байсан уу? Чиний мэдэх ёстой зүйл бол энэ: Бурхан намайг төгс болгох эсэхээс үл хамааран би Бурханыг дагах ёстой; одоо Түүний хийдэг бүхэн сайн бөгөөд миний төлөө хийгддэг, ингэснээр зан чанар маань өөрчлөгдөж, бид Сатаны нөлөөнөөс өөрсдийгөө салган, бузар газар нутагт төрсөн ч бохир хольцоос өөрсдийгөө салгаж, бузар булай болон Сатаны нөлөөнөөс ангижирч, үүнийг орхих боломжтой болж чадна. Мэдээж, чамаас шаарддаг зүйл энэ боловч Бурханы хувьд энэ нь ердөө л байлдан дагуулалт бөгөөд ингэснээр хүмүүс дуулгавартай дагах шийдвэртэй байж, Бурханы бүх зохион байгуулалтад захирагдаж чадна. Ийм маягаар аливаа зүйл гүйцэлдэнэ. Өнөөдөр ихэнх хүмүүс аль хэдийн байлдан дагуулагдсан боловч тэдний дотор тэрслүү, дуулгаваргүй байдал ихээхэн байсаар байдаг. Хүмүүсийн

жинхэнэ биеийн хэмжээ мөн л хэтэрхий жаахан бөгөөд итгэл найдвар, хэтийн ирээдүй байх л юм бол тэд эрч хүчээр дүүрдэг; итгэл найдвар, хэтийн ирээдүй байхгүй бол тэд сөрөг болж, бүр Бурханыг орхин явах тухай ч боддог. Түүнчлэн, хэвийн хүн чанарыг амьдран харуулахаар чармайх хүсэл хүмүүст тийм ч их байдаггүй. Үүнийг хүлээн зөвшөөрөх аргагүй. Тиймээс Би байлдан дагуулалтын тухай мөн л ярих ёстой. Үнэн хэрэгтээ төгс төгөлдөржилт нь байлдан дагуулалттай нэгэн зэрэг явагддаг: Чамайг байлдан дагуулагдахад төгс болгуулахын эхний үр нөлөө ч бас гардаг. Байлдан дагуулагдах болон төгс болгуулах хоёрын хоорондох ялгаа нь хүмүүсийн өөрчлөлтийн түвшний дагуу байдаг. Байлдан дагуулагдах нь төгс болгуулахын эхний алхам бөгөөд тэд бүрэн төгс болгуулчихсан гэсэн үг биш, мөн Бурхан тэднийг бүрэн олж авсан гэдгийг ч нотолдоггүй. Хүмүүс байлдан дагуулагдсаныхаа дараа зан чанарт нь зарим нэг өөрчлөлт гардаг боловч ийм өөрчлөлт нь Бурханаар бүрэн авхуулсан хүмүүсийнхээс хавьгүй бага байдаг. Өнөөдөр хийгдэж байгаа зүйл бол хүмүүсийг төгс болгох анхан шатны ажил буюу тэднийг байлдан дагуулах явдал бөгөөд хэрвээ чи байлдан дагуулагдаж чадахгүй бол Бурханаар төгс болгуулж, Түүгээр бүрэн авхуулах ямар ч аргагүй байх болно. Чи ердөө гэсгээлт, шүүлтийн цөөн хэдэн үгийг олж авах боловч тэдгээр нь зүрх сэтгэлийг чинь бүрмөсөн өөрчилж чадахгүй. Тиймээс чи таягдан хаягдах хүмүүсийн нэг нь болно; энэ нь ширээн дээрх тансаг зоогийг харсан ч идэхгүй байгаагаас өөрцгүй. Энэ нь эмгэнэлт дүр зураг биш гэж үү? Иймээс чи өөрчлөлтийг эрж хайх ёстой: Байлдан дагуулагдаж, эсвэл төгс болгуулж байсан ч бай, энэ хоёр нь чамд өөрчлөлт байгаа эсэхтэй болон дуулгавартай юу, үгүй юу гэдэгтэй чинь холбоотой бөгөөд Бурхан чамайг авах эсэхийг тодорхойлдог. “Байлдан дагуулагдах”, “төгс болгуулах” нь зүгээр л өөрчлөлт болон дуулгавартай байдлын хэмжээнд, түүнчлэн Бурханыг гэх хайр чинь хэр цэвэр ариун бэ гэдэгт суурилдаг гэдгийг мэдэж ав. Өнөөдөр шаарддаг зүйл бол чи бүрэн төгс болгуулах явдал, гэхдээ эхлээд чи байлдан дагуулагдах ёстой—чи Бурханы гэсгээлт, шүүлтийн талаар хангалттай мэдлэгтэй, дагах итгэлтэй байж, өөрчлөлтийг эрж хайдаг, Бурханы тухай мэдлэгийг эрж хайдаг нэгэн байх ёстой. Тэр үед л чи төгс болгуулахаар эрж хайдаг хүн болно. Төгс болгуулах явцдаа байлдан дагуулагдана, мөн байлдан дагуулагдах явцдаа төгс болгуулна гэдгээ та нар ойлгох ёстой. Өнөөдөр чи төгс болгуулахаар эрж хайж, эсвэл гаднах хүн чанараа өөрчилж, хэв чанараа сайжруулахаар эрж хайж болох боловч өнөөдөр Бурханы хийдэг бүхэн утга учиртай, ашиг тустай гэдгийг ойлгож чаддаг байх нь хамгийн чухал юм: Энэ нь, бузар газарт төрсөн чамд бузар булайгаас зугтаж, үүнээс ангижрах боломж олгодог, мөн Сатаны нөлөөг даван гарч, Сатаны харанхуйн нөлөөг орхих боломж олгодог. Эдгээр зүйлд анхаарлаа төвлөрүүлснээр чи энэхүү бузар газарт хамгаалагддаг. Эцэст нь чамаас ямар гэрчлэл өгөхийг хүсдэг вэ? Чи бузар газарт төрсөн ч бохир заваанаар дахин хэзээ ч сэвтэхгүйгээр ариун болж чаддаг, Сатаны эзэмшил дор амьдардаг ч Сатаны нөлөөнөөс салж, Сатанаар эзэмдүүлдэг ч үгүй, дарлуулдаг ч үгүй бөгөөд Төгс

Хүчитийн гарт амьдардаг. Энэ бол гэрчлэл, мөн Сатантай хийсэн тулааны ялалтын нотолгоо. Чи Сатаныг хаяж чаддаг бөгөөд амьдран харуулдаг зүйлдээ сатанлаг зан чанарыг илчлэхээ болиод, харин хүнийг бүтээхдээ Бурханы хүнээс шаардсан зүйл буюу хэвийн хүн чанар, хэвийн эрүүл ухаан, хэвийн гүн ойлголт, Бурханыг хайрлах хэвийн шийдвэр, Бурханд үнэнч байдлыг амьдран харуулдаг. Энэ нь Бурханы бүтээлийн хийдэг гэрчлэл билээ. “Бид бузар газарт төрсөн боловч Бурханы хамгаалалтын улмаас, Түүний удирдлагын улмаас, Тэр биднийг байлдан дагуулсан учраас өөрсдийгөө Сатаны нөлөөнөөс салгасан. Өнөөдөр дуулгавартай байж чадаж байгаа маань ч бас Бурханаар байлдан дагуулагдахын үр нөлөө бөгөөд бидний сайнаас, эсвэл бид аяндаа Бурханыг хайрласнаас болоогүй. Бурхан биднийг сонгож, урьдчилан тогтоосон учраас л бид өнөөдөр байлдан дагуулагдсан ба Түүнд гэрчлэл хийх чадвартай болж, Түүнд үйлчилж чаддаг; бас Тэр биднийг сонгож, биднийг хамгаалсан учраас л бид аврагдаж, Сатаны эзэмшлээс ангижирсан ба бузар завааныг орхиж, агуу улаан лууны үндэстэн дотор ариусгагдаж чаддаг” гэж чи хэлдэг. Түүнчлэн, гаднаа амьдран харуулдаг зүйл чинь, чи хэвийн хүн чанартай, хэлдэг зүйл чинь эрүүл ухаантай бөгөөд хэвийн хүний төрхийг амьдран харуулдаг гэдгийг чинь харуулна. Бусад хүмүүс чамайг харах үедээ “Энэ агуу улаан лууны дүр төрх биш гэж үү?” гэж хэлэх ёсгүй. Эгч нарын биеэ авч явах байдал эгч нарт тохирдоггүй, ах нарын биеэ авч явах байдал ах нарт тохирдоггүй ба ариун хүмүүсийн ёс зүй огт байдаггүй. Тэгэхээр хүмүүс “Бурхан тэднийг Моабын удам гэж хэлсэнд гайхах зүйл алга, Түүний түмэн зөв!” хэмээн хэлнэ. Хүмүүс та нарыг хараад, “Бурхан та нарыг Моабын удам гэж хэлсэн хэдий ч амьдран харуулдаг зүйл чинь Сатаны нөлөөг орхисон гэдгийг чинь нотоллоо; хэдий тэдгээр зүйл та нарын дотор байсаар байгаа ч та нар тэдгээрээс нүүр буруулж чаддаг ба бүрэн байлдан дагуулагдсан гэдгийг чинь энэ нь харуулдаг” гэж хэлбэл байлдан дагуулагдаж, аврагдсан та нар: “Моабын удам гэдэг нь үнэн боловч бид Бурханаар авруулсан ба хэдийгээр Моабын удам урьд нь хаягдаж, хараагдаж, Израилийн ард түмнээр Харь үндэстэн дунд цөлөгдсөн ч өнөөдөр Бурхан биднийг аварсан. Бид бүх хүнээс хамгийн завхарсан нь гэдэг үнэн—үүнийг Бурхан зарлигдсан, энэ бол баримт, хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй. Гэвч өнөөдөр бид энэ нөлөөнөөс зугтсан. Бид өвөг дээдсээ үзэн яддаг, мөн өвөг дээдсээсээ нүүр буруулж, үүнийг бүрмөсөн хаяж, Бурханы бүх зохицуулалтыг дуулгавартай дагаж, Бурханы хүслийн дагуу үйлдэж, бидэнд тавьдаг Түүний шаардлагыг биелүүлж, Бурханы хүслийг хангалуун байлгахыг хүсэж байна. Моаб Бурханаас урвасан, Бурханы хүслийн дагуу үйлдээгүй бөгөөд Бурхан түүнийг үзэн ядсан. Гэвч бид Бурханы зүрх сэтгэлийг анхаарах ёстой ба өнөөдөр Бурханы хүслийг нэгэнт ойлгосон учраас Бурханаас урваж болохгүй, харин хуучин өвөг дээдсээсээ татгалзах ёстой!” гэж хэлнэ. Урьд нь Би агуу улаан луунаас татгалзах тухай ярьсан бөгөөд өнөөдөр хүмүүсийн хуучин өвөг дээдсээс татгалзах тухай голчлон ярилаа. Энэ бол хүмүүсийн байлдан дагуулалтын тухай нэг гэрчлэл бөгөөд өнөөдөр хэрхэн

ордгоос чинь үл хамааран, энэ хэсэг дэх чиний гэрчлэл дутуу дулимаг байх ёсгүй.

Хүмүүсийн хэв чанар хэтэрхий дорд, хэвийн хүн чанараар дэндүү дутмаг, хариу үйлдэл нь хэтэрхий удаан, дэндүү хойрго, Сатаны завхрал тэднийг хөшүүн, маанаг болгож орхисон бөгөөд тэд ганц, хоёр жилийн дотор бүрэн өөрчлөгдөж чадахгүй хэдий ч хамтран ажиллах шийдвэртэй байх ёстой. Энэ нь бас Сатаны өмнөх гэрчлэл юм гэж хэлж болно. Өнөөдрийн гэрчлэл бол одоогийн байлдан дагуулалтын ажлаар хүрсэн үр нөлөө, түүнчлэн ирээдүйн дагагчдад зориулсан үлгэр дуурайл, загвар юм. Ирээдүйд энэ нь бүх үндэстэнд түгнэ; Хятадад хийгддэг ажил бүх үндэстэнд түгнэ. Моабын удам дэлхийн бүх хүнээс хамгийн дорд нь юм. “Хамын үр удам л хамгийн дорд биш үү?” гэж зарим хүн асуудаг. Агуу улаан лууны үр сад болон Хамын үр удам нь өөр өөр бэлгэдлийн ач холбогдолтой бөгөөд Хамын үр удам бол өөр асуудал юм: Тэд яаж ч хараагдсан бай, Ноагийн үр удам хэвээр; харин тэгэхэд Моабын гарал үүсэл цэвэр ариун биш байсан бөгөөд Моаб садар самуун явдлаас гарсан, ялгаа нь үүнд оршдог. Хоёулаа хараагдсан хэдий ч тэдний байр суурь адил байгаагүй, иймээс Моабын үр удам бүх хүнээс хамгийн дорд нь юм—бүх хүнээс хамгийн дорд хүмүүсийг байлдан дагуулахаас илүү үнэмшилтэй баримт гэж үгүй. Эцсийн өдрүүдийн ажил бүх дүрэм журмыг эвддэг ба чи хараагдсан ч бай, эсвэл шийтгүүлсэн ч бай хамаагүй, Миний ажилд туслан, өнөөдрийн байлдан дагуулалтын ажилд тус болсоор байгаа цагт, мөн Моабын үр удам, эсвэл агуу улаан лууны үр сад эсэхээсээ үл хамааран, ажлын энэ үе шатанд Бурханы бүтээлийн үүргийг биелүүлж, чадах бүхнээ хийсээр байгаа цагт зохих үр дүнд хүрэх болно. Чи бол агуу улаан лууны үр сад, мөн Моабын үр удам; дүгнэн хэлбэл, мах, цустай хүн бүхэн Бурханы бүтээл бөгөөд Бүтээгчээр бүтээгдсэн билээ. Чи бол Бурханы бүтээл, чамд ямар ч сонголт байх ёсгүй ба энэ нь чиний үүрэг. Мэдээж өнөөдөр Бүтээгчийн ажил бүхий л ертөнц рүү чиглэдэг. Хэний үр удам байхаас үл хамааран, юун түрүүнд чи бол Бурханы бүтээлүүдийн нэг, Моабын үр удам болох та нар бол Бурханы бүтээлүүдийн нэг хэсэг, цорын ганц ялгаа нь та нар зүгээр л арай дорд үнэ цэнтэй. Өнөөдөр Бурханы ажил бүх бүтээлийн дунд хийгдэж, бүхий л орчлон ертөнц рүү чиглэдэг тул Өөрийнхөө ажлыг хийхийн тулд Бүтээгч ямар ч хүмүүс, хэрэг явдал, эсвэл зүйлсийг сонгож болно. Тэрээр хэний үр удам болохыг чинь анхаардаггүй; чи Түүний бүтээлүүдийн нэг бөгөөд Түүний ажил буюу байлдан дагуулалт, гэрчлэлийн ажилд тус болсоор байгаа цагт Тэр Өөрийн ажлыг чам дээр ямар ч эргэлзээгүйгээр гүйцэтгэнэ. Энэ нь, Бурхан Харь үндэстнүүдийн дунд, ялангуяа хараагдсан, дорд хүмүүсийн дунд хэзээ ч ажиллахгүй; хараагдсан хүмүүсийн хувьд тэдний ирээдүйн бүх үр удам хэзээ ч аврагдах боломжгүйгээр, үүрд хараагдана; Бурхан хэзээ ч Харь үндэстнүүдийн нутагт буун ирж, ажиллахгүй, бузар газарт хэзээ ч хөл тавихгүй, учир нь Тэр бол ариун билээ хэмээх хүмүүсийн уламжлалт үзлийг нураадаг. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил энэ бүх үзлийг нураасаан. Бурхан бол бүх бүтээлийн Бурхан, тэнгэр, газар, бүх зүйлийг ноёрхдог бөгөөд зөвхөн Израилийн ард түмний Бурхан биш юм.

Тиймээс Хятад дахь энэхүү ажил дээд зэргийн ач холбогдолтой бөгөөд бүх үндэстний дунд түгэхгүй гэж үү? Ирээдүйн агуу гэрчлэл зөвхөн Хятадаар хязгаарлагдахгүй; хэрвээ Бурхан та нарыг л байлдан дагуулсан бол чөтгөрүүдийг итгүүлж чадах байсан уу? Тэд байлдан дагуулагдахыг, эсвэл Бурханы агуу хүчийг ойлгодоггүй ба бүхий л орчлон ертөнц даяарх Бурханы сонгосон хүмүүс энэ ажлын эцсийн үр нөлөөг харах үед л бүх бүтээл байлдан дагуулагдана. Моабын үр удмаас илүү хоцрогдсон, завхарсан хэн ч үгүй. Хамгийн их завхарсан, Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй, Бурхан байдаг гэдэгт итгэдэггүй энэ хүмүүс байлдан дагуулагдаж, өөрсдийн амаар Бурханыг хүлээн зөвшөөрч, Түүнийг магтаж, Түүнийг хайрлаж чаддаг болох үед л энэ нь байлдан дагуулалтын гэрчлэл байх болно. Хэдий та нар Петр биш ч гэлээ Петрийн төрхийг амьдран харуулж, Петр болон Иовын гэрчлэлийг эзэмшиж чаддаг ба энэ нь хамгийн агуу гэрчлэл юм. Эцэстээ чи: “Бид израильчууд биш, харин Моабын хаягдсан үр удам, бид Петр биш, түүнийх шиг хэв чанартай байх чадваргүй, бас Иов ч биш бөгөөд Бурханы төлөө зовж, өөрийгөө Бурханд зориулахаар шийдсэн Паултай өөрсдийгөө харьцуулж ч чадахгүй, бид маш их хоцрогдсон, тиймээс Бурханы ерөөлийг эдлэх эрхгүй. Бурхан өнөөдөр биднийг мөн л дээш өргөсөн; иймээс бид Бурханыг сэтгэл хангалуун болгох ёстой ба хангалтгүй хэв чанартай, чадвартай хэдий ч бид Бурханыг сэтгэл хангалуун болгохыг хүсэж байна—бидэнд ийм шийдвэр байгаа. Бид бол Моабын үр удам бөгөөд хараагдсан. Үүнийг Бурхан зарлигдсан ба бид үүнийг өөрчлөх чадваргүй, гэхдээ бидний амьдран харуулж байгаа зүйл болон мэдлэг өөрчлөгдөж болно, бас бид Бурханыг сэтгэл хангалуун байлгахаар шийдсэн” гэж хэлнэ. Чамд ийм шийдвэр байх үед, байлдан дагуулагдах тухай гэрчлэлтэй гэдгийг чинь энэ нь нотолно.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН 3

Байлдан дагуулалтын ажлын зорьсон үр нөлөө нь юун түрүүнд хүний махан бие тэрслэхээ болих явдал юм; өөрөөр хэлбэл, хүний оюун ухаан Бурханы талаар шинэ мэдлэгтэй болж, зүрх сэтгэл нь Бурханыг бүрэн дуулгавартай дагаж, Бурханы төлөө тэмүүлэх явдал юм. Ааш авир юм уу махан бие нь өөрчлөгдөхөд хүмүүсийг байлдан дагуулагдсан гэж тооцдоггүй; хүний бодол, ухамсар болон эрүүл ухаан өөрчлөгдөх үед, өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хандлага чинь бүхэлдээ өөрчлөгдөх үед—чи Бурханаар байлдан дагуулагдсан байх болно. Чи дуулгавартай байхаар шийдэж, шинэ сэтгэлгээтэй болж, өөрийн ямар ч үзэл, санаа зорилгыг Бурханы үг болон ажилтай холихоо больж, уураг тархи чинь хэвийн байдлаар бодож чадах үед—өөрөөр хэлбэл, бүх зүрх сэтгэлээрээ Бурханы төлөө зүтгэх үед—чи бүрэн байлдан дагуулагдсан төрлийн хүн юм. Шашинд олон хүн насан туршдаа асар их зовдог: Тэд биеэ захирч, загалмайгаа үүрч, бүр үхлийн ирмэгт байх үедээ ч зовж, тэвчсээр байдаг! Зарим нь өөрсдийнхөө насан эцэслэх өглөө ч мацаг барьж байдаг.

Бүхий л амьдралдаа тэд сайхан хоол хүнс, хувцас хунараас татгалзаж, зовоход л анхаарлаа хандуулдаг. Тэд биеэ захирч, махан биеэ хаяж чаддаг. Зовлон тэвчсэнийх нь төлөө тэдний эр зоригийг магтууштай. Гэвч тэдний бодол, үзэл, сэтгэл санааны байдал болон хуучин уг чанар нь өчүүхэн төдий ч харьцалт туулаагүй байдаг. Тэдэнд өөрсдийнх нь талаарх ямар ч жинхэнэ мэдлэг байдаггүй. Тэдний сэтгэл дэх Бурханы дүр нь тодорхойгүй Бурханы уламжлалт дүр байдаг. Бурханы төлөө зовох шийдвэр нь тэдний урам зориг болон хүн чанарынх нь сайн ёс жудгаас үүдэн гардаг. Хэдий тэд Бурханд итгэдэг ч Бурханыг ойлгодоггүй, Түүний хүслийг ч мэддэггүй. Тэд ердөө л Бурханы төлөө сохроор ажиллаж, зовдог. Тэд ялган таних чадварт ямар ч ач холбогдол өгдөггүй, үйлчлэл нь яаж Бурханы хүслийг үнэхээр биелүүлэх талаар багахан анхаардаг бөгөөд Бурханы талаарх мэдлэгт хэрхэн хүрэхээ бүр ч мэддэггүй. Тэдний үйлчилдэг Бурхан нь төрөлх дүрээрээ байгаа Бурхан биш, харин өөрсдийнх нь төсөөлсөн Бурхан, өөрсдийнх нь сонсож дуулсан юм уу ном зохиолын үлгэр домгоос уншсан л Бурхан юм. Тэгээд тэд өөрсдийн баялаг төсөөлөл, сүсэг бишрэлээ ашиглан Бурханы төлөө зовж, Бурханы хийхийг хүсдэг ажлыг хариуцдаг. Тэдний үйлчлэл хэтэрхий оновчгүй байдаг болохоор чухамдаа хэн нь ч Бурханы хүслийн дагуу үйлчилж үнэхээр чаддаггүй. Тэд Бурханы шүүлт, гэсгээлт, цэвэршүүлэлт, төгс болголтыг туулаагүй, мөн үнэнийг ашиглан хэн ч тэднийг залж чиглүүлээгүй учраас хэчнээн дуртай зовдгоос үл хамааран үйлчлэлийн талаарх анхдагч үзэл бодол болон сэтгэлд нь байгаа Бурханы дүр өөрчлөгдөлгүй үлддэг. Аврагч Есүст итгэдэг байлаа ч гэсэн, тэдний нэг нь ч Аврагчийг ер харж байгаагүй. Тэд үлгэр домог, цуу ярианаас л Түүний талаар мэддэг. Үүний үр дүнд, тэдний үйлчлэл нь сохор хүн эцэгтээ үйлчлэхтэй адилаар нүдээ анин таамгаар үйлчлэхээс хэтэрдэггүй. Ийм төрлийн үйлчлэлээр эцэстээ юунд хүрч чадах вэ? Хэн үүнийг сайшаах юм бэ? Эхнээсээ эцсээ хүртэл тэдний үйлчлэл нэгэн хэвийн хэвээр үлддэг; тэд зөвхөн хүний сургаалыг л хүлээн авдаг бөгөөд байгаа байдал, дуртай зүйлдээ л үндэслэн үйлчилдэг. Энэ нь ямар шагнал авчирч чадах юм бэ? Есүсийг харсан Петр хүртэл Бурханы хүслийн дагуу хэрхэн үйлчлэхээ мэдээгүй; тэрээр эцэст нь хөгширсөн хойноо л мэдэж авсан юм. Тэгвэл өчүүхэн төдий ч харьцалт, засалт туулаагүй, залж чиглүүлэх хэн ч байхгүй тэр сохор хүмүүсийн тухайд юу гэх вэ? Өнөөдөр та нарын дундах олон хүний үйлчлэл энэ сохор хүмүүсийнхтэй адилхан биш гэж үү? Шүүлт, засалт, харьцалт хүлээн аваагүй, өөрчлөгдөөгүй бүх хүн—бүгд бүрэн байлдан дагуулагдаагүй хүмүүс бус уу? Ийм хүмүүс ямар хэрэгтэй юм бэ? Чиний сэтгэхүй, амьдралын талаарх мэдлэг, Бурханы талаарх мэдлэгт ямар ч шинэ өөрчлөлт гардаггүй, үнэндээ юу ч олж авдаггүй бол чи үйлчлэлээрээ ер бусын юунд ч хүрэхгүй! Үзэгдэл болон Бурханы ажлын тухай шинэ мэдлэггүй бол чи байлдан дагуулагдаагүй. Тэгвэл Бурханыг дагаж байгаа чинь зовж, мацаг барьдаг хүмүүстэй адил, өчүүхэн үнэ цэнтэй байх болно! Хийдэг зүйлд нь багахан гэрчлэл байдаг учраас л тэдний үйлчлэл хий дэмий юм гэж Би хэлдэг! Тэр хүмүүс насан туршдаа

зовж, шоронд цагаа өнгөрүүлдэг; тэд ямагт тэвчиж, хайрлан, үргэлж загалмай үүрдэг, дэлхий ертөнцөд дооглуулж, гологдож, бэрхшээл бүрийг туулж, эцсээ хүртэл дуулгавартай байдаг ч мөн л байлдан дагуулагддаггүй бөгөөд байлдан дагуулагдах тухай ямар ч гэрчлэл хийж чаддаггүй. Тэд асар их зовсон ч дотроо Бурханыг огт мэддэггүй. Тэдний хуучин сэтгэхүй, хуучин үзэл, шашны зан үйл, хүний бий болгосон мэдлэг болон хүний үзэл санааны аль нь ч харьцалт амсаагүй. Шинэ ойлголтын өчүүхэн ч сэжүүр тэдэнд байдаггүй. Бурханы талаарх тэдний мэдлэгийн багахан нь ч үнэн зөв, оновчтой байдаггүй. Тэд Бурханы хүслийг буруугаар ойлгосон. Энэ нь Бурханд үйлчилж байгаа хэрэг үү? Бурханы талаарх урьдын мэдлэг чинь ямар ч байлаа гэсэн, өнөөдөр хэвээрээ үлдэж, Бурхан юу ч хийлээ гэсэн Бурханы талаарх мэдлэг чинь өөрийн үзэл, санаанд үндэслэсээр байвал, өөрөөр хэлбэл, Бурханы талаарх ямар ч шинэ, жинхэнэ мэдлэг чамд байдаггүй, чи Бурханы жинхэнэ дүр төрх болон зан чанарыг мэдэж чаддаггүй бол, мөн Бурханы талаарх мэдлэг чинь одоо ч феодалын, мухар сүсэгт сэтгэлгээгээр удирдуулж, хүний үзэл, төсөөллөөс төрөн гардаг хэвээр бол чи байлдан дагуулагдсангүй. Одоо чамд Миний хэлж буй олон үг бүгд чамайг мэдлэгтэй болгож, энэхүү мэдлэгээр чамайг илүү шинэлэг, үнэн зөв мэдлэг рүү хөтлөх зорилготой; бас чамд байгаа хуучин үзэл, хуучин мэдлэгийг үгүй хийх зорилготой, ингэснээр чи шинэ мэдлэгтэй болно. Хэрвээ чи Миний үгийг үнэхээр идэж уувал мэдлэг чинь мэдэгдэхүйц өөрчлөгдөнө. Чи дуулгавартай зүрх сэтгэлээр Бурханы үгийг идэж, ууж байгаа цагт үзэл бодол чинь өөрчлөгдөнө. Чи удаа дараагийн гэсгээлтийг хүлээн авч чадаж байгаа цагт хуучин сэтгэхүй чинь аажмаар өөрчлөгдөнө. Чиний хуучин сэтгэхүй бүхэлдээ шинээр солигдсон цагт хэрэгжүүлэлт чинь ч бас үүнийг даган өөрчлөгдөнө. Ийм маягаар чиний үйлчлэл улам бүр оновчтой болж, Бурханы хүслийг улам их биелүүлж чадна. Хэрвээ чи өөрийн амьдрал, хүний амьдралын талаарх мэдлэг болон Бурханы талаарх олон үзлээ өөрчилж чадвал төрөлх байдал чинь аажмаар багасна. Гагцхүү энэ нь л Бурхан хүмүүсийг байлдан дагуулах үеийн үр нөлөө бөгөөд хүмүүст гардаг өөрчлөлт юм. Бурханд итгэхдээ чи биеэ захирч, тэвчиж, зовохыг л мэддэг бөгөөд энэ нь зөв үү, буруу юу гэдгийг мэддэггүй, бүр хэний төлөө хийдгээ ч мэддэггүй бол ийм хэрэгжүүлэлт яаж өөрчлөлт рүү хөтөлж чадах юм бэ?

Та нараас Миний шаарддаг зүйл бол махан биеэ хазаарлаж, эсвэл уураг тархиа дураараа бодож сэтгэхийг нь болиулах явдал биш гэдгийг ойлгож ав. Энэ нь ажлын зорилго ч биш, яг одоо хийх хэрэгтэй ажил ч биш. Өөрсдийгөө өөрчлөхийн тулд яг одоо та нар эерэг талаас мэдлэгтэй болох ёстой. Хамгийн их хэрэгтэй үйлдэл бол өөрсдийгөө Бурханы үгээр зэвсэглэх буюу өнөөгийн үзэгдэл болон үнэнээр өөрсдийгөө бүрэн зэвсэглэж, цаашлаад тэдгээрийг хэрэгжүүлэх явдал юм. Энэ бол та нарын хариуцлага. Би та нараас бүр илүү их гэрэлтүүлэлтийг эрж хайж, олж авахыг шаардаагүй байна. Одоогоор та нарт тийм биеийн хэмжээ ердөө байхгүй. Та нараас шаарддаг зүйл бол Бурханы үгийг идэж, уухын тулд чадах бүхнээ хийх явдал юм. Та нар Бурханы ажлыг ойлгож, өөрсдийн уг чанар, мөн чанар болон

хуучин амьдралыг мэдэх ёстой. Ялангуяа та нар урьдын андуу ташаа, утгагүй хэрэгжүүлэлт болон хийсэн үйлдлээ мэдэх хэрэгтэй. Өөрчлөгдөхийн тулд сэтгэхүйгээ өөрчлөхөөс эхлэх ёстой. Эхлээд хуучин сэтгэхүйгээ шинээр сольж, шинэ сэтгэхүйгээрээ өөрийн үг, үйлдэл, амьдралыг удирдуул. Өнөөдөр та бүгдээс шаарддаг зүйл энэ юм. Сохроор бүү хэрэгжүүл, эсвэл сохроор бүү дага. Та нар үндэс суурь, зорилготой байх ёстой. Өөрсдийгөө бүү хуур. Бурханд итгэх итгэл чинь яг юуны төлөө болох, үүнээс юу олж авах ёстой болон яг одоо юунд орох ёстойгоо та нар мэдэх ёстой. Чи энэ бүхнийг мэдэх шаардлагатай.

Та нарын одоо орох ёстой зүйл бол амьдралаа дээшлүүлж, хэв чанараа өсгөх явдал юм. Түүнчлэн, урьдын хуучин үзэл бодлоо өөрчилж, сэтгэхүйгээ өөрчилж, үзлээ өөрчлөх хэрэгтэй. Бүхий л амьдралд чинь шинэчлэлт хэрэгтэй. Бурханы үйл хэргийн талаарх мэдлэг чинь өөрчлөгдөж, Бурханы хэлдэг бүхний үнэний талаар шинэ мэдлэгтэй болж, доторх мэдлэг чинь өсөх үед чиний амьдрал сайжирч эхэлнэ. Одоо хүмүүсийн хийдэг, хэлдэг бүх зүйл бодитой. Эдгээр нь хоосон сургаал биш, харин ч хүмүүсийн аминд хэрэгтэй, тэдний эзэмших ёстой зүйлс юм. Энэ нь байлдан дагуулалтын ажлын үеэр хүмүүст гардаг өөрчлөлт, хүмүүсийн туулах ёстой өөрчлөлт, байлдан дагуулагдсаных нь дараах үр нөлөө билээ. Чи сэтгэхүйгээ өөрчилж, сэтгэл санааны шинэ хандлагатай болж, өөрийн үзэл, санаа зорилго болон урьдын логик үндэслэлийг няцааж, дотор чинь гүн үндэслэсэн зүйлсийг хаяж, Бурханд итгэх итгэлийн талаар шинэ мэдлэгтэй болсон үед гэрчлэл чинь өргөгдөж, бүхий л оршихуй чинь үнэхээр өөрчлөгдсөн байх болно. Энэ бүхэн нь хамгийн бодитой, хамгийн жинхэнэ, хамгийн үндсэн зүйлс—өнгөрсөн үед хүмүүсийн хүрч чадаагүй зүйлс, мөн тэдний харилцаж чаддаггүй байсан зүйлс юм. Тэдгээр нь Сүнсний жинхэнэ ажил билээ. Чи урьд нь Библийг яг яаж ойлгож байсан бэ? Үүнийг өнөөдөр харьцуулаад үзвэл чи мэдэх болно. Урьд нь чи Мосе, Петр, Паул эсвэл библийн тэр бүх үг, үзэл бодлыг сэтгэл санаандаа дээдэлж, өндөрт өргөсөн. Одоо хэрвээ чамаас Библийг өндөрт өргөхийг хүсвэл чи үүнийг хийх үү? Библи нь хүний бичсэн хэтэрхий олон тэмдэглэлийг агуулдаг ба Бурханы ажлын хоёр үе шатны тухай хүний бүртгэл төдий юм гэдгийг чи харна. Энэ бол түүхийн ном юм. Тэгвэл үүний талаарх мэдлэг чинь өөрчлөгдсөн гэсэн үг биш гэж үү? Хэрвээ чи өнөөдөр Матайн Сайн мэдээнд бичигдсэн Есүсийн угийн бичгийг харвал “Есүсийн угийн бичиг ээ? Утгагүй юм! Энэ бол Есүсийн биш, Иосефын угийн бичиг. Есүс, Иосеф хоёрын хооронд ямар ч холбоо байхгүй” хэмээн хэлнэ. Одоо Библийг харах үед үүний талаарх мэдлэг чинь өөр байдаг, өөрөөр хэлбэл, чиний үзэл бодол өөрчлөгдсөн бөгөөд чи шашны ахмад эрдэмтдээс илүү өндөр түвшний мэдлэгтэй байдаг. Энэхүү угийн бичигт ямар нэгэн зүйл байна гэж хэн нэгэн хэлбэл чи: “Үүнд юу байх юм бэ? Тэгвэл тайлбарлаад өг дөө. Есүс, Иосеф хоёр хоорондоо хамаагүй. Чи тэрийг мэддэггүй гэж үү? Есүст угийн бичиг байж болох уу? Есүс яаж өвөг дээдэстэй байж болох юм бэ? Тэр яаж хүний үр удам байж болох юм бэ? Түүний махбод Мариагаас төрсөн; Түүний Сүнс бол хүний сүнс биш, харин Бурханы Сүнс.

Есүс бол Бурханы хайртай хүү, тэгэхээр Тэр угийн бичигтэй байж болох уу? Газар дээр байхдаа Тэр хүн төрөлхтний нэгэн гишүүн байгаагүй, иймээс Тэр яаж угийн бичигтэй байх юм бэ?" гэж хариулна. Чи угийн бичгийг шинжилж, дотоод үнэнийг тодорхой тайлбарлаж, ойлгосон зүйлээ хуваалцах үед тэр хүн хэлэх үггүй болно. Зарим хүн Библиэс эш татаж, "Есүс угийн бичигтэй байсан. Чиний өнөөдрийн Бурхан угийн бичигтэй юү?" гэж асууна. Чи тэгэхэд нь тэдэнд өөрийн хамгийн бодитой мэдлэгийнхээ талаар хэлж, ийм маягаар мэдлэг чинь үр нөлөө үзүүлсэн байх болно. Үнэндээ Есүс Иосефтэй ямар ч хамаагүй бөгөөд Абрахамтай бүр ч холбоогүй; Есүс зүгээр л Израильд төрсөн юм. Гэхдээ Бурхан бол израиль хүн биш, израильчуудын үр удам ч биш. Израильд төрлөө гээд Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэсэн утгатай байх албагүй. Өөрийнхөө ажлын төлөө л Тэр бие махбодтой болох ажлыг гүйцэтгэсэн юм. Бурхан бол орчлон ертөнц дээрх бүх бүтээлийн Бурхан билээ. Тэр зүгээр л ажлынхаа нэг үе шатыг Израильд хийгээд, дараа нь Харь үндэстнүүдийн дунд ажиллаж эхэлсэн. Гэсэн ч хүмүүс Есүсийг израильчуудын Бурхан гэж үзсэн бөгөөд цаашлаад Түүнийг израильчуудын дунд, Давидын үр удмын дунд тавьсан. Эцсийн өдрүүдэд Еховагийн нэр Харь үндэстнүүдийн дунд агуу болно гэж Библид бичсэн байдаг, энэ нь Бурхан эцсийн өдрүүдэд Харь үндэстнүүдийн дунд ажиллана гэсэн үг юм. Бурхан Иудейд бие махбодтой болсон нь Бурхан зөвхөн иудейчүүдийг хайрладаг гэдгийг илтгэдэггүй. Ажил нь шаардсан учраас л тийм зүйл болсон; (израильчууд Түүний сонгосон хүмүүс байсан учраас) Бурхан Израильд л бие махбодтой болох ёстой байсан юм биш. Бурханы сонгосон хүмүүс Харь үндэстнүүдийн дунд ч бас байдаг бус уу? Есүс Иудейд ажиллаж дууссаны дараа уг ажил Харь үндэстнүүдэд өргөжсөн. (Израильчууд Израилиас бусад бүх үндэстнийг "Харь үндэстнүүд" гэж нэрлэдэг байв.) Үнэндээ тэр Харь үндэстнүүдэд ч гэсэн Бурханы сонгосон хүмүүс байсан; зүгээр л тухайн үед тэнд ямар ч ажил хараахан хийгдээгүй байсан юм. Харь үндэстнүүдэд ямар ч ажил хийгдээгүй байхад Израильд ажлын хоёр үе шат явагдсан учраас хүмүүс Израилийг тэгж их онцолдог. Харь үндэстнүүдийн дундах ажил өнөөдөр л эхэлж байгаа бөгөөд тийм учраас үүнийг хүлээн зөвшөөрөх нь хүмүүст тун хэцүү байдаг. Хэрвээ чи энэ бүхнийг тодорхой ойлгож, өөрийн болгож, зөвөөр авч үзэж чадвал өнөөдрийн болон урьдын Бурханы талаар нарийн зөв мэдлэгтэй болох бөгөөд энэ шинэ мэдлэг нь түүхэн туршид ариун хүмүүсийн эзэмшиж байсан Бурханы талаарх мэдлэгээс илүү өндөр байх болно. Хэрвээ чи өнөөдрийн ажлыг туулж, Бурханы хувийн айлдварыг өнөөдөр сонсдог ч Бурханыг бүхэлд нь мэддэггүй бол, эрэл хайгуул чинь үргэлж байсан шигээ үлдэн, ямар ч шинэ зүйлээр солигддоггүй бол, ялангуяа хэрвээ чи энэ бүх байлдан дагуулалтын ажлыг туулдаг ч эцэстээ чамаас ямар ч өөрчлөлт харагддаггүй бол итгэл чинь, өлсгөлөнгөө дарахын тулд л талх хайдаг хүмүүсийнхтэй адил биш гэж үү? Тэр тохиолдолд байлдан дагуулалтын ажил чамд ямар ч үр нөлөө үзүүлээгүй байх болно. Тэгвэл чи таягдан хаягдах хүмүүсийн нэг болохгүй гэж үү?

Байлдан дагуулалтын бүх ажил төгсгөлдөө очих үед, Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан биш, харин бүх бүтээлийн Бурхан юм гэдгийг та нар бүгд ойлгох шаардлагатай. Тэрээр зөвхөн израильчуудыг ч биш, бүх хүн төрөлхтнийг бүтээсэн. Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан, эсвэл Бурхан Израилийн гаднах өөр ямар ч үндэстэнд бие махбодтой болох боломжгүй гэж хэлдэг бол чи байлдан дагуулалтын ажлын үеэр ямар нэгэн мэдлэг хараахан олж аваагүй бөгөөд Бурхан бол чиний Бурхан гэдгийг өчүүхэн төдий ч таньдаггүй; Бурхан Израилиас Хятад руу шилжиж, арга буюу чиний Бурхан болсон гэж л чи хүлээн зөвшөөрдөг. Хэрвээ чи аливааг ингэж үзсээр байгаа бол Миний ажил чамд ямар ч үр өгөөжгүй байсан ба чи Миний хэлсэн нэг ч зүйлийг ойлгосонгүй. Эцэст нь хэрвээ чи Матай шиг Надад зориулсан өөр нэг угийн бичгийг бичиж, Надад тохирох өвөг дээдсийг олж, Миний “зөв” уг үндсийг олж өгөөд—ингэснээр Бурхан хоёр удаа бие махбод болохдоо хоёр угийн бичигтэй байвал энэ нь дэлхий дээрх хамгийн том хошин шог болохгүй гэж үү? Надад угийн бичиг олж өгсөн энэ “сайн санаатай хүн” чи Бурханыг хуваасан хүн болохгүй гэж үү? Чи энэ нүглийн ачааг үүрч чадах уу? Энэ бүх байлдан дагуулалтын ажлын дараа хэрвээ чи одоо ч Бурхан бол бүх бүтээлийн Бурхан гэдэгт итгэхгүй байгаа бол, Бурхан бол израильчуудын л Бурхан гэж бодсоор байгаа бол чи Бурханыг ил тод эсэргүүцдэг хүн биш гэж үү? Өнөөдөр чамайг байлдан дагуулахын зорилго нь Бурхан бол чиний Бурхан, бас бусдын Бурхан, хамгийн чухал нь Түүнийг хайрладаг бүхний Бурхан, бүх бүтээлийн Бурхан гэдгийг чамаар хүлээн зөвшөөрүүлэх явдал юм. Тэр бол израильчуудын Бурхан бөгөөд Египетийн ард түмний ч Бурхан юм. Тэр бол англичуудын Бурхан, америкчуудын Бурхан билээ. Тэр бол зөвхөн Адам Евагийн Бурхан биш, бас тэдний бүх үр удмын Бурхан. Тэр бол тэнгэр дэх бүх зүйлийн, мөн газар дахь бүх зүйлийн Бурхан билээ. Израильчууд ч бай, Харь үндэстэн ч бай, бүх гэр бүл бүгд нэгэн Бурханы гарт байдаг. Тэр Израильд хэдэн мянган жил ажиллаж, Иудейд нэгэнтээ төрөөд зогсохгүй, өнөөдөр агуу улаан лууны цагариглан хэвтдэг газар болох Хятадад бууж ирсэн. Хэрвээ Иудейд төрсөн нь Түүнийг иудейчүүдийн Хаан болгодог юм бол та бүхний дунд өнөөдөр бууж ирэх нь Түүнийг та бүгдийн Бурхан болгохгүй гэж үү? Тэр израильчуудыг удирдаж, Иудейд төрсөн бөгөөд бас Харь үндэстний нутагт төрсөн. Түүний бүх ажил Өөрийн бүтээсэн бүх хүн төрөлхтний төлөө хийгддэг бус уу? Тэр израильчуудыг зуу дахин их хайрлаж, Харь үндэстнүүдийг мянга дахин их жигшдэг үү? Энэ та нарын үзэл биш гэж үү? Бурхан хэзээ ч та нарын Бурхан байгаагүй юм биш, харин ч та нар л Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй; Бурхан та нарын Бурхан байхыг хүсдэггүй юм биш, харин ч та нар л Бурханыг голдог. Бүтээгдсэн зүйлийн дотроос хэн Төгс Хүчитийн гарт байдаггүй вэ? Та нарыг өнөөдөр байлдан дагуулахын зорилго нь Бурхан бол та нарын Бурханаас өөр хэн ч биш гэдгийг та нараар хүлээн зөвшөөрүүлэх явдал биш гэж үү? Хэрвээ та нар, Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэж үзсэн хэвээр, мөн Израиль дахь Давидын гэр бол Бурханы төрөлтийн уг сурвалж бөгөөд Израилиас

өөр ямар ч үндэстэн Бурханыг “бий болгох” эрхгүй, тэр ч бүү хэл ямар ч Харь үндэстний гэр бүл Еховагийн ажлыг биечлэн хүлээн авч чадахгүй гэж бодсоор байвал энэ нь чамайг зөрүүд эсэргүүцэгч болгохгүй гэж үү? Израиль дээр үргэлж харцаа бүү тогтоо. Бурхан өнөөдөр яг энд та нарын дунд байгаа. Бас тэнгэр лүү ч бүү ширтсээр бай. Тэнгэр дэх Бурханаа хүсэмжлэхээ боль! Бурхан та нарын дунд ирсэн, тэгэхээр Тэр яаж тэнгэрт байж болох юм бэ? Чи Бурханд тийм ч удаан итгээгүй атлаа Түүний талаар ихээхэн үзэл өвөрлөн, израильчуудын Бурхан Өөрийн биеэр та нарыг нигүүлсэнэ гэдгийг нягтлан бодохгүй байж зүрхлэхдээ тулдаг. Өөрсдөө тэвчихийн аргагүй бохир болохоор та нар Бурхан биечлэн гарч ирэхийг хэрхэн харах талаар бодохгүй байж зүрхлэхдээ ч тулдаг. Бас Бурхан Харь үндэстний нутагт хэрхэн биечлэн бууж ирэх талаар хэзээ ч бодож байгаагүй. Тэр Синаи Уул, эсвэл Чидун Уулан дээр буун ирж, израильчуудад харагдах учиртай. Харь үндэстнүүд (өөрөөр хэлбэл, Израилийн гаднах хүмүүс) нь бүгд Түүний жигшил зэвүүцлийн бай биш гэж үү? Тэр яаж тэдний дунд биечлэн ажиллаж чадах юм бэ? Энэ бүхэн нь олон жилийн туршид та нарын бий болгосон, гүн үндэслэсэн үзэл юм. Та нарыг өнөөдөр байлдан дагуулахын зорилго нь эдгээр үзлийг чинь эвдэх явдал. Тиймээс Бурхан Синаи Уулан дээр, эсвэл Чидун Уулан дээр биш, харин урьд нь хэзээ ч удирдаж байгаагүй хүмүүсийнхээ дунд—та нарын дунд биечлэн илрэхийг та нар хардаг. Бурхан Өөрийн ажлын хоёр үе шатыг Израильд хийсний дараа израильчууд болон бүх Харь үндэстний аль аль нь, Бурхан бүх зүйлийг бүтээсэн нь үнэн боловч Харь үндэстнүүдийн Бурхан биш, зөвхөн израильчуудын Бурхан байхыг л хүсэж байгаа гэх үзэлтэй болсон. Израильчууд, Бурхан зөвхөн бидний Бурхан байж болно, харин Харь үндэстнүүд та нарын Бурхан биш, та нар Еховаг хүндэлдэггүй учраас бидний Бурхан—Ехова та нарыг жигшдэг гэж итгэдэг. Иудей хүмүүс ч бас ингэж итгэдэг: Эзэн Есүс иудей хүмүүс бидний дүр төрхийг авсан бөгөөд иудей хүмүүсийн тэмдгийг тээдэг Бурхан юм. Бидний дунд л Бурхан ажилладаг. Бурханы дүр төрх болон бидний дүр төрх адилхан; бидний дүр төрх Бурханыхтай төстэй. Эзэн Есүс бол иудейчүүд бидний Хаан; Харь үндэстнүүд тийм агуу авралыг хүлээн авах эрхгүй. Эзэн Есүс бол иудейчүүд бидний төлөөх нүглийн тахил. Ажлын тэр хоёр үе шатны үндсэн дээр л израильчууд болон иудей хүмүүс энэ бүх үзлийг бий болгосон. Тэд Бурханыг өөрсдийнх нь гэж түрэмгийлэн зарладаг ба Бурхан бол Харь үндэстнүүдийн ч Бурхан мөн гэдгийг зөвшөөрдөггүй. Ийм маягаар Харь үндэстнүүдийн зүрх сэтгэлд Бурхан хоосон зай болсон. Учир нь, Бурхан Харь үндэстнүүдийн Бурхан байхыг хүсдэггүй, Тэр зөвхөн израильчуудад буюу Өөрийн сонгосон хүмүүст л дуртай ба ялангуяа Өөрийг нь дагаж байсан шавь нар болох иудейчүүдэд л дуртай гэж хүн бүр итгэх болсон юм. Ехова, Есүс хоёрын хийсэн ажил бүх хүн төрөлхтнийг амьд үлдээхийн төлөө гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Бурхан бол Израилийн гадна төрсөн та бүхний Бурхан юм гэдгийг чи одоо хүлээн зөвшөөрч байна уу? Бурхан өнөөдөр яг энд та нарын дунд байгаа бус уу? Энэ нь зүүд байж болохгүй биз дээ? Та нар энэ бодит байдлыг хүлээн зөвшөөрдөггүй юу? Та нар үүнд

итгэж, эсвэл энэ талаар бодож зүрхэлдэггүй. Үүнийг яаж харахаас чинь үл хамааран, Бурхан яг энд та нарын дунд байгаа бус уу? Та нар энэ үгэнд итгэхээс мөн л айж байна уу? Энэ өдрөөс эхлээд бүх байлдан дагуулагдсан хүмүүс болон Бурханы дагагчид болохыг хүсдэг бүхэн Бурханы сонгосон хүмүүс биш гэж үү? Өнөөдрийн дагагчид та бүхэн, Израилийн гаднах сонгогдсон хүмүүс биш гэж үү? Та нарын байр суурь израильчуудынхтай адилгүй гэж үү? Та нарын танин мэдэх ёстой зүйл чинь энэ бүхэн биш үү? Энэ нь та нарыг байлдан дагуулах ажлын зорилго биш гэж үү? Нэгэнт та нар Бурханыг харж чадах учраас Тэр эхнээсээ аваад ирээдүйд ч үүрд та нарын Бурхан байх болно. Та нар бүгд Түүнийг дагаж, Түүний үнэнч дуулгавартай бүтээл байхыг хүссээр байгаа цагт Тэр та нарыг орхихгүй.

Хүмүүс Бурханыг хайрлахаар хэр их эрмэлздэгээс үл хамааран, тэд өдий хүртэл Түүнийг дагахдаа ерөнхийдөө дуулгавартай байсаар ирсэн. Ажлын энэ үе шат дуусаж, эцэстээ хүрэх үед л тэд бүрэн дүүрэн гэмшинэ. Тэр нь хүмүүс үнэхээр байлдан дагуулагдсан байх үе юм. Яг одоо тэд байлдан дагуулагдах үйл явцад л байгаа. Ажил дуусах мөчид тэд бүрэн байлдан дагуулагдана, гэхдээ яг одоо тийм биш! Хүн болгон үнэмшдэг байлаа ч, тэд бүрэн байлдан дагуулагдсан гэсэн үг биш. Яагаад гэвэл, одоогоор хүмүүс бодит үйл явдлыг биш, зөвхөн үгийг харсан бөгөөд тэд хэчнээн гүн гүнзгий итгэдэг нь хамаагүй, тодорхой мэдэхгүй хэвээр үлддэг. Тийм учраас тэрхүү хамгийн сүүлчийн бодит үйл явдлаар л үг бодит байдал болж, хүмүүс бүрэн байлдан дагуулагдана. Яг одоо, хүмүүс урьд нь хэзээ ч сонсож байгаагүй олон нууцыг сонсдог учраас байлдан дагуулагддаг. Гэхдээ дотроо тэд дор бүрнээ, Бурханы үг бүр биелж байгааг өөрсдөд нь харуулдаг зарим бодит үйл явдлыг эрж хайж, хүлээсээр байдаг. Зөвхөн тэр үед л тэд бүрэн үнэмшинэ. Эцэстээ бүгд эдгээр биелсэн бодит байдлыг харж, эдгээр бодит байдал нь тэднийг итгэлтэй болгох үед тэд зүрх сэтгэлдээ, үг яриандаа, нүдэндээ итгэл үнэмшлийг харуулж, зүрх сэтгэлийнхээ гүнээс бүрэн үнэмшинэ. Хүний уг чанар ийм байдаг: Та нар үг бүгд биелж байгааг харах хэрэгтэй байдаг, мөн зарим бодитой үйл явдал тохиолдож байгааг харж, зарим хүнд гай гамшиг тохиож байгааг харах хэрэгтэй байдаг, тэгвэл зүрх сэтгэлийнхээ гүнд бүрэн үнэмшинэ. Иудейчүүдийн адилаар та нар тэмдэг, гайхамшгуудыг харахад асар их ач холбогдол өгдөг. Гэсэн ч та нар тэмдэг, гайхамшиг байдаг гэдгийг, мөн нүдийг чинь асар ихээр нээх учиртай бодит байдал тохиолдсоор байгаа гэдгийг харж ер чаддаггүй. Хэн нэгэн тэнгэрээс бууж ирэх ч бай, үүлэн багана та нарт үг хэлэх ч бай, та нарын нэгнээс Би чөтгөр шулмыг зайлуулах ч бай, эсвэл Миний дуу хоолой та нарын дунд аянга шиг нүргэлэх ч бай, та нар үргэлж иймэрхүү үйл явдлыг харахыг хүссэн, үргэлж хүссээр ч байх болно. Бурханд итгэхэд хамгийн том хүсэл чинь Бурхан ирж, та нарт биечлэн тэмдэг үзүүлэхийг харах явдал гэж хэлж болно. Тэгвэл сэтгэл чинь ханана. Хүмүүс та нарыг байлдан дагуулахын тулд Би тэнгэр, газрыг бүтээхтэй төстэй ажил гүйцэтгэж, дээр нь нэмээд нэг төрлийн тэмдэг үзүүлэх хэрэгтэй. Тэгвэл та нарын зүрх сэтгэл бүрэн байлдан дагуулагдана.

БАЙЛДАН ДАГУУЛАЛТЫН АЖЛЫН ДОТООД ҮНЭН 4

Төгс болгуулах гэж юу гэсэн үг вэ? Байлдан дагуулагдах гэж юу гэсэн үг вэ? Байлдан дагуулагдахын тулд хүмүүс ямар шалгуурыг хангах ёстой вэ? Төгс болгуулахын тулд ямар шалгуурыг хангах ёстой вэ? Байлдан дагуулах, төгс болгох нь хоёулаа хүнийг бүрэн төгс болгох зорилготой, ингэснээр тэр анхдагч төрхөө сэргээж, завхарсан сатанлаг зан чанар болон Сатаны нөлөөнөөс ангижирч болох юм. Энэхүү байлдан дагуулалт нь хүнийг хүн болгох үйл явцын эхэнд болдог; үнэндээ энэ нь ажлын эхний алхам юм. Төгс болгох нь хоёр дахь алхам бөгөөд төгсгөлийн ажил билээ. Хүн бүр байлдан дагуулагдах үйл явцыг туулах ёстой. Тэгэхгүй бол тэд Бурханыг мэдэх ямар ч аргагүй, Бурхан байдаг гэдгийг ч мэдэхгүй, өөрөөр хэлбэл, тэдний хувьд Бурханыг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Хэрвээ хүмүүс Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй бол тэдний хувьд бас Бурханаар бүрэн төгс болгуулах боломжгүй байдаг, чи бүрэн төгс болгуулах энэхүү шалгуурыг хангадаггүй. Хэрвээ чи бүр Бурханыг ч хүлээн зөвшөөрдөггүй бол Түүнийг яаж мэдэж чадах юм бэ? Яаж Түүнийг эрэлхийлж чадах юм бэ? Чи Түүнд гэрчлэл хийж ч чадахгүй, тэр ч бүү хэл Түүнийг сэтгэл хангалуун болгох итгэлтэй байж ч чадахгүй. Иймээс бүрэн төгс болгуулахыг хүсдэг хэний ч хувьд эхний алхам нь байлдан дагуулалтын ажлыг туулах явдал байх ёстой. Энэ бол эхний нөхцөл. Гэвч байлдан дагуулах, төгс болгох нь хоёулаа хүмүүсийг хүн болгож, өөрчлөхийн төлөө байдаг бөгөөд аль аль нь хүнийг удирдах ажлын нэг хэсэг юм. Хүнийг бүрэн гүйцэд болгоход энэ хоёр алхам хоёулаа хэрэгтэй бөгөөд алийг нь ч орхигдуулж болохгүй. “Байлдан дагуулагдах” гэдэг нь тийм ч сайхан сонсогддоггүй нь үнэн боловч үнэн хэрэгтээ хэн нэгнийг байлдан дагуулах үйл явц нь түүнийг өөрчлөх үйл явц юм. Байлдан дагуулагдмагц завхарсан зан чанар чинь бүрэн арилаагүй байж болох ч чи ядаж л үүнийг мэдэж авсан байна. Байлдан дагуулалтын ажлаар дамжуулан чи дорд хүн чанараа, мөн ихээхэн дуулгаваргүй байдлаа мэдэж авсан байх болно. Хэдийгээр чи байлдан дагуулалтын ажлын богинохон хугацаанд эдгээр зүйлийг хаяж, эсвэл өөрчилж чадахгүй ч тэдгээрийг мэдэж авах бөгөөд энэ нь төгс болгуулах суурийг чинь тавина. Иймээс байлдан дагуулах болон төгс болгох нь хоёулаа хүмүүсийг өөрчилж, тэднийг завхарсан сатанлаг зан чанараас нь салгахын тулд хийгддэг, ингэснээр тэд өөрсдийгөө Бурханд бүрэн өгч чадна. Байлдан дагуулагдана гэдэг нь ердөө хүмүүсийн зан чанарыг өөрчлөх эхний алхам, мөн хүмүүс өөрсдийгөө Бурханд бүрэн өгөх эхний алхам бөгөөд төгс болгуулах алхмаас доогуур юм. Байлдан дагуулагдсан хүний амь зан чанар төгс болгуулсан хүнийхээс хамаагүй бага өөрчлөгддөг. Байлдан дагуулагдах болон төгс болгуулах нь үзэл баримтлалын хувьд нэг нэгээсээ өөр, учир нь тэдгээр нь ажлын өөр өөр үе шат бөгөөд хүмүүсийг өөр өөр стандартад байлгадаг; байлдан дагуулалт нь хүмүүсийг доогуур стандартад байлгадаг байхад төгс болголт нь илүү өндөр стандартад байлгадаг. Төгс болгуулсан хүмүүс нь зөв шударга хүмүүс, ариун болгуулсан

хүмүүс юм; тэд бол хүн төрөлхтнийг удирдах ажлын биелэлт буюу эцсийн бүтээгдэхүүн билээ. Хэдийгээр тэд төгс хүмүүс биш ч утга учиртай амьдралаар амьдрахаар эрж хайдаг хүмүүс юм. Харин байлдан дагуулагдсан хүмүүс Бурханы оршин тогтнолыг үгээрээ л хүлээн зөвшөөрдөг; Бурхан бие махбодтой болж, Үг махбодоор илэрсэн, Бурхан шүүлт, гэсгээлтийн ажил хийхийн тулд газар дээр ирсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн тэд, Бурханы шүүлт болон гэсгээлт, цохилт болон цэвэршүүлэлт нь бүгд хүнд ашиг тустай гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тэд саяхнаас л бага зэрэг хүний төрхтэй болж эхэлсэн. Тэдэнд амьдралын талаарх зарим нэг ойлголт байдаг ч мөн л бүдэг бадаг хэвээр үлддэг. Өөрөөр хэлбэл, тэд хүн чанарыг л эзэмшиж эхэлж байгаа. Энэ нь байлдан дагуулагдахын үр нөлөө юм. Хүмүүс төгс болгуулах замд хөл тавих үед хуучин зан чанараа өөрчлөх чадвартай болдог. Түүнчлэн, тэдний амь өссөөр байдаг ба тэд аажмаар үнэнд илүү гүн гүнзгий ордог. Тэд дэлхий ертөнцийг үзэн ядаж, үнэнийг эрэлхийлдэггүй бүх хүнийг үзэн ядаж чаддаг. Тэд ялангуяа өөрсдийгөө үзэн яддаг, гэхдээ үүнээс ч илүүтэйгээр өөрсдийгөө тодорхой мэддэг. Тэгээд үнэнээр амьдрахыг хүсэж, үнэнийг эрэлхийлэхийг зорилгоо болгодог. Тэд уураг тархиныхаа бий болгосон бодол дотор амьдрахыг хүсдэггүй бөгөөд хүний өөрийгөө зөвтгөдөг байдал, онгироо, ихэрхүү занг жигшдэг. Тэд ёс зүйн өндөр мэдрэмжтэй ярьдаг, ялган таних чадвар, мэргэн ухаантайгаар аливааг зохицуулж, Бурханд үнэнч, дуулгавартай байдаг. Гэсгээлт, шүүлтийн тохиолдлыг туулбал тэд идэвхгүй, сул дорой болдоггүйгээр үл барам, Бурханы энэхүү гэсгээлт, шүүлтэд талархдаг. Бурханы шүүлт, гэсгээлтгүйгээр байж чадахгүй; энэ нь тэднийг хамгаалдаг гэж тэд итгэдэг. Тэд амар амгалан, баяр хөөр, өлсгөлөнгөө дарах талх эрж хайх итгэлийг эрэлхийлдэггүй. Түр зуурын махан биеийн зугаа цэнгэлийн араас ч хөөцөлддөггүй. Энэ нь төгс болгуулсан хүмүүст гардаг зүйл юм. Хүмүүс байлдан дагуулагдсаныхаа дараа Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч тийнхүү хүлээн зөвшөөрсөн нь хязгаарлагдмал байдлаар тэднээс харагддаг. Үг нь махбодоор илэрсэн гэдэг нь үнэндээ юу гэсэн үг вэ? Бие махбодтой болох гэж юу гэсэн үг вэ? Бие махбодтой болсон Бурхан юу хийсэн бэ? Түүний ажлын зорилго, ач холбогдол юу вэ? Түүний маш их ажлыг туулж, махбод дахь Түүний үйл хэргийг туулсны дараа чи юу олж авсан бэ? Энэ бүх зүйлийг ойлгосны дараа л чи байлдан дагуулагдсан хүн болно. Хэрвээ чи, Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг гэж л хэлдэг боловч хаях учиртай зүйлийг хаядаггүй, орхих ёстой махан биеийн зугаа цэнгэлийг орхиж чаддаггүй, харин ч урьдынх шигээ махан биеийн тав тухыг байнга улиглан хүсэж, ах эгч нарын эсрэг атгаг сэжгийг тавьж явуулж чаддаггүй, олон энгийн хэрэгжүүлэлтийг гүйцэтгэхдээ ямар ч төлөөс төлдөггүй бол хараахан байлдан дагуулагдаагүйг чинь тэр нь нотолдог. Тэр тохиолдолд, чи ихийг ойлгодог байлаа ч гэсэн, тэр бүхэн нь ямар ч хэрэггүй байх болно. Байлдан дагуулагдсан хүмүүс нь анхан шатны өөрчлөлт, анхан шатны оролтод хүрсэн хүмүүс юм. Бурханы шүүлт, гэсгээлтийг туулах нь хүмүүст Бурханы талаарх анхан шатны мэдлэг болон үнэний

талаарх анхан шатны ойлголтыг өгдөг. Чи илүү гүн гүнзгий бодит байдал, илүү дэлгэрэнгүй үнэн рүү бүрэн орж чадахгүй байж болох боловч махан биеийн зугаа цэнгэл, эсвэл хувийн байр суурьтай чинь холбоотой олон энгийн үнэнийг бодит амьдралдаа хэрэгжүүлж чаддаг. Энэ бүхэн нь байлдан дагуулагдах үйл явцад хүмүүст гардаг үр нөлөө юм. Зан чанарын өөрчлөлтийг ч бас байлдан дагуулагдсан хүмүүсээс харж болно; жишээлбэл, тэдний хувцаслаж, биеэ авч явдаг байдал, амьдардаг байдал бүгд өөрчлөгдөж болно. Бурханд итгэх итгэлийн талаарх тэдний үзэл бодол өөрчлөгдөж, тэд өөрсдийн эрэл хайгуулын зорилгын талаар тодорхой мэдэж, илүү өндөр хүсэл эрмэлзэлтэй болдог. Байлдан дагуулалтын ажлын явцад тэдний амь зан чанарт ч бас холбогдох өөрчлөлт гардаг. Өөрчлөлт гардаг боловч тэдгээр нь өнгөцхөн, анхан шатных бөгөөд төгс болгуулсан хүмүүсийн зан чанар болон эрэл хайгуулын зорилго дахь өөрчлөлтөөс хавьгүй дор байдаг. Хэрвээ байлдан дагуулагдах явцад хүний зан чанар огтхон ч өөрчлөгддөггүй, тэрээр өчүүхэн төдий ч үнэнийг олж авдаггүй бол ийм хүн зүгээр л хог новш бөгөөд огт хэрэггүй! Байлдан дагуулагдаагүй хүмүүс төгс болгуулж чадахгүй! Хэрвээ хүн зөвхөн байлдан дагуулагдахыг л хичээвэл, байлдан дагуулалтын ажлын үеэр зан чанарт нь зарим нэг зохих өөрчлөлт харагддаг ч гэсэн тэрээр бүрэн төгс болгуулж чадахгүй. Тэр өөрийн олж авсан анхны үнэнийг ч бас алдана. Байлдан дагуулагдсан болон төгс болгуулсан хүмүүсийн зан чанарын өөрчлөлтөд үлэмж их ялгаа бий. Гэхдээ байлдан дагуулагдах нь өөрчлөлтийн эхний алхам мөн; энэ нь суурь билээ. Анхны энэ өөрчлөлт дутмаг байгаа нь, тухайн хүн Бурханыг үнэндээ огт мэддэггүй гэдгийн баталгаа юм, учир нь энэхүү мэдлэг шүүлтээс ирдэг бөгөөд ийм шүүлт нь байлдан дагуулалтын ажлын үндсэн хэсэг билээ. Иймээс төгс болгуулсан бүхэн эхлээд байлдан дагуулагдах ёстой; эс бөгөөс тэдний хувьд төгс болгуулах ямар ч аргагүй.

Чи бие махбодтой болсон Бурханыг хүлээн зөвшөөрдөг, Үг махбодоор илэрснийг хүлээн зөвшөөрдөг гэж хэлдэг атлаа Түүний нүднээс далдуур зарим зүйлийг хийж, Түүний шаарддаг зүйлд харшилдаг зүйл хийдэг бөгөөд зүрх сэтгэлдээ Түүнээс ер айдаггүй. Энэ нь Бурханыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг үү? Чи Түүний хэлдэг зүйлийг хүлээн зөвшөөрдөг боловч хийж чадах зүйлээ хэрэгжүүлдэггүй, Түүний замыг ч баримталдаггүй. Энэ нь Бурханыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг үү? Чи Түүнийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч Түүнийг хэзээ ч хүндэлдэггүй ба Түүнээс сэрэмжлэх л сэтгэлтэй байдаг. Түүний ажлыг харж, хүлээн зөвшөөрсөн бөгөөд Тэр бол Бурхан гэдгийг мэддэг хэрнээ хөндий хайнга, огт өөрчлөгдөхгүй хэвээр үлдвэл чи мөн л байлдан дагуулагдаагүй хүн юм. Байлдан дагуулагдсан хүмүүс чадах бүхнээ хийх ёстой бөгөөд илүү өндөр үнэнд орж чадахгүй, эдгээр үнэн нь тэдний хувьд хүршгүй хэдий ч ийм хүмүүс зүрх сэтгэлдээ үүнд хүрэхийг хүсдэг. Учир нь, тэдний хүлээн авч чадах зүйлд хязгаар байдаг ба хэрэгжүүлж чаддаг зүйл нь бас хэмжээ, хязгаартай байдаг. Гэхдээ тэд ядаж л чадах бүхнээ хийх ёстой бөгөөд хэрвээ чи эдгээр зүйлийг хийж чадвал энэ нь байлдан

дагуулалтын ажлаас үүдэн гарсан үр нөлөө юм. “Хүний чадахгүй маш олон үгийг Тэр хэлсэн гэдгийг харвал хэрвээ Тэр Бурхан биш юм бол өөр хэн байх вэ?” гэж чи хэллээ гэж үзье. Ийм бодолтой байлаа гээд Бурханыг хүлээн зөвшөөрдөг гэсэн үг биш. Хэрвээ чи Бурханыг хүлээн зөвшөөрдөг бол бодит үйлдлээрээ харуулах ёстой. Чуулганыг удирдаж байгаа ч зөв шударга байдлыг хэрэгжүүлж чаддаггүй бол, мөнгө, эд хөрөнгөд шунаж, чуулганы санг өөртөө үргэлж халаасалдаг бол энэ нь Бурхан байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг мөн үү? Бурхан бол төгс хүчит бөгөөд хүндлэл хүртүүштэй. Хэрвээ чи Бурхан байдаг гэдгийг үнэхээр хүлээн зөвшөөрдөг бол яаж айхгүй байж чадах юм бэ? Чи тийм жигшүүртэй үйл хийх чадвартай бол Түүнийг үнэхээр хүлээн зөвшөөрдөг үү? Чи Бурханд итгэдэг гэж үү? Чиний итгэдэг зүйл чинь тодорхойгүй Бурхан; тиймээс чи айдаггүй! Бурханыг үнэхээр хүлээн зөвшөөрч, мэддэг хүмүүс бүгд Түүнээс айдаг ба Түүнийг эсэргүүцэх, эсвэл өөрсдийн мөс чанарыг зовоох зүйл хийхээс айдаг; тэд ялангуяа, Бурханы хүслийн эсрэг гэдгийг нь мэддэг юуг ч хийхээс айдаг. Үүнийг л Бурханы оршин тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаад тооцож болно. Эцэг эх чинь Бурханд итгэхийг чинь болиулахаар оролдох үед чи юу хийх ёстой вэ? Үл итгэгч нөхөр чинь чамд сайн хандаж байх үед чи Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Ах эгч нар чинь чамайг үзэн ядах үед Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Хэрвээ чи Түүнийг хүлээн зөвшөөрдөг бол энэ бүх хэрэг явдал дээр зохих ёсоор үйлдэж, бодит байдлыг амьдран харуулна. Хэрвээ чи бодитой үйлдэл хийж чадахгүй, харин зөвхөн Бурханы оршин тогтнолыг хүлээн зөвшөөрдөг гэж л хэлбэл зүгээр л хоосон яригч юм! Чи Түүнд итгэж, Түүнийг хүлээн зөвшөөрдөг гэж хэлдэг боловч ямар байдлаар Түүнийг хүлээн зөвшөөрдөг вэ? Ямар байдлаар чи Түүнд итгэдэг вэ? Чи Түүнээс айдаг уу? Түүнийг хүндэлдэг үү? Сэтгэлийнхээ гүнд Түүнийг хайрладаг уу? Чи зовуурилж, түшиж тулах хэн ч үгүй байх үедээ Бурханы хайр татам байдлыг мэдэрдэг ч дараа нь энэ бүхнээ таг мартдаг. Тэр нь Бурханыг хайрлаж байгаа хэрэг биш, Бурханд итгэж байгаа ч хэрэг биш! Тэгвэл эцсийн эцэст хүн юунд хүрээсэй гэж Бурхан хүсдэг вэ? Өөрийгөө ихэд чухалчилж, юмыг хүлээн авч, ойлгохдоо хурдан гэж бодож, бусдыг хянаж, бусдыг дорд үзэж, харагдах байдлаар нь хүмүүсийг шүүж, гэм зэмгүй хүмүүсийг дээрэлхэж, чуулганы мөнгөнд шунах гэх мэт Миний дурдсан энэ бүх байдал буюу энэ бүх сатанлаг завхарсан зан чанарын нэг хэсгээс салах үед л байлдан дагуулагдсан чинь харагдана.

Байлдан дагуулалтын ажил хүмүүс та нар дээр хийгддэг нь хамгийн гүн гүнзгий ач холбогдолтой: Нэг талаар, энэхүү ажлын зорилго нь бүлэг хүмүүсийг төгс болгох явдал, өөрөөр хэлбэл, тэднийг төгс болгосноор тэд бүлэг ялагч—бүрэн төгс болгуулсан эхний бүлэг хүмүүс буюу анхны үр жимс болж болох юм. Нөгөө талаар, энэ нь бүтээгдсэн зүйлсэд Бурханы хайрыг эдлүүлж, Бурханы бүрэн дүүрэн, хамгийн агуу авралыг хүртээж, хүнд өршөөл, хайр энэрлийг л эдлүүлээд зогсохгүй үүнээс ч чухал нь гэсгээлт, шүүлтийг эдлүүлэхийн төлөө байдаг. Дэлхий бүтээгдсэнээс эхлээд өнөөг хүртэл Өөрийнхөө ажлаар Бурханы хийсэн бүхэн бол

хүнийг огтхон ч үзэн ядаагүй хайр билээ. Чиний харсан гэсгээлт, шүүлт ч гэсэн бас хайр, илүү жинхэнэ, илүү бодитой хайр, хүмүүсийг хүний амьдралын зөв зам руу хөтөлдөг хайр юм. Өөр нэг талаар, энэ нь Сатаны өмнө гэрчлэл хийхийн төлөө юм. Дахиад нэг талаас бол, энэ нь ирээдүйн сайн мэдээний ажлыг түгээх суурийг тавихын төлөө байдаг. Түүний хийсэн бүх ажил нь хүмүүсийг хэвийн хүн шиг амьдруулахын тулд хүний амьдралын зөв зам руу хөтлөх зорилготой байсан, учир нь хүмүүс хэрхэн амьдрахаа мэддэггүй бөгөөд энэхүү удирдамжгүйгээр чи хоосон амьдралаар л амьдарна; амьдрал чинь үнэ цэнгүй, утга учиргүй байх ба чи хэвийн хүн байж огт чадахгүй. Энэ нь хүнийг байлдан дагуулахын хамгийн гүн гүнзгий ач холбогдол билээ. Та нар бүгд Моабын удам юм; та нар дээр байлдан дагуулалтын ажил хийх нь агуу аврал мөн. Та нар бүгд нүгэлт, завхай газар амьдардаг бөгөөд бүгд завхай, нүгэлтэй. Өнөөдөр та нар Бурханыг хараад зогсохгүй, бүр ч чухал нь гэсгээлт, шүүлтийг хүлээн авч, үнэхээр гүн гүнзгий авралыг хүртсэн, өөрөөр хэлбэл, Бурханы хамгийн агуу хайрыг хүлээн авсан. Өөрийн хийдэг бүхэндээ Бурхан та нарыг үнэхээр хайрладаг. Түүнд ямар ч муу санаа зорилго байхгүй. Та нарын нүглээс болж л Тэр та нарыг шүүдэг, ингэснээр та нар өөрсдийгөө шинжилж, энэхүү үлэмж их авралыг хүлээн авна. Энэ бүхэн нь хүнийг бүрэн төгс болгох зорилгоор хийгддэг. Эхнээсээ эцсээ хүртэл Бурхан хүнийг аврахын тулд чадах бүхнээ хийсээр ирсэн бөгөөд Өөрийн бүтээсэн хүмүүсийг Өөрийн гараар бүрэн устгахыг хүсдэггүй. Өнөөдөр Тэр та нарын дунд ажиллахаар ирсэн; энэ нь бүр ч илүү их аврал биш гэж үү? Хэрвээ Тэр та нарыг үзсэн ядсан бол та нарыг биечлэн удирдахын тулд ийм их хэмжээний ажлыг мөн л хийх байсан уу? Яагаад Тэр ингэж зовох ёстой юм бэ? Бурхан та нарыг үзэн яддаггүй, эсвэл та нарын эсрэг муу санаа агуулдаггүй. Бурханы хайр бол хамгийн жинхэнэ хайр гэдгийг та нар мэдэх ёстой. Хүмүүс дуулгаваргүй учраас л Тэр шүүлтээр дамжуулан тэднийг аврах хэрэгтэй болсон; тэгэхгүй бол хүмүүсийг аврах боломжгүй байх байв. Та нар хэрхэн амьдрахыг мэддэггүй, бүр хэрхэн амьдрах талаар ч ойлгодоггүй учраас, мөн энэхүү завхай, нүгэлтэй газарт амьдардаг ба өөрсдөө завхай, бузар диаволууд учраас та нарыг бүр их доройтуулж Тэр тэвчдэггүй, одоогийнх шигээ энэхүү бохир бузар газарт амьдарч, Сатанд хүссэнээр нь гишгэлүүлэхийг чинь харж тэвчдэггүй, та нарыг Үхэгсдийн орон руу унагаж ч тэвчдэггүй. Тэрээр энэ бүлэг хүмүүсийг олж авч, та нарыг бүрэн аврахыг л хүсдэг. Энэ нь та нар дээр байлдан дагуулалтын ажлыг хийхийн үндсэн зорилго бөгөөд энэ нь гагцхүү авралын төлөө байдаг. Чам дээр хийгддэг бүхэн хайр, аврал юм гэдгийг хэрвээ чи харж чаддаггүй бол, хэрвээ чи энэ нь зүгээр л арга барил, хүнийг тарчлаах зам, итгэхийн аргагүй зүйл гэж боддог бол зовлон, бэрхшээл туулахын тулд өөрийнхөө ертөнц рүү буцсан нь дээр! Хэрвээ чи энэ урсгалд байж, энэ шүүлт, энэ энгүй авралыг эдэлж, хүний ертөнцийн хаанаас ч олдохгүй энэ бүх ерөөлийг эдэлж, энэ хайрыг эдлэхийг хүсэж байгаа бол сайн бай: Байлдан дагуулалтын ажлыг хүлээн авахын тулд энэ урсгалд бай, тэгвэл төгс болгуулж чадна. Өнөөдөр чи Бурханы шүүлтийн улмаас бага зэрэг зовлон

шаналал, цэвэршүүлэлт туулж болох ч энэхүү зовлон шаналалд үнэ цэн, утга учир бий. Бурханы гэсгээлт, шүүлт хүмүүсийг цэвэршүүлж, хайр найргүй илчилдэг хэдий ч зорилго нь нүглийнх нь төлөө тэднийг шийтгэж, тэдний махан биеийг шийтгэхийн төлөө байдаг—энэ ажлын юу ч тэдний махан биеийг яллан сүйрүүлэхээр зорьдоггүй. Үгийн хатуу чанд илчлэлт нь бүгд чамайг зөв зам руу хөтлөх зорилготой. Та нар энэ ажлын маш ихийг биечлэн туулсан ба энэ нь та нарыг муу зам руу хөтлөөгүй нь тодорхой! Энэ бүхэн нь чамаар хэвийн хүн чанарыг амьдран харуулуулахын төлөө байдаг бөгөөд энэ бүхэнд хэвийн хүн чанараараа хүрэх боломжтой. Бурханы ажлын алхам бүр нь чиний хэрэгцээнд үндэслэж, сул талын чинь дагуу, бодит биеийн хэмжээний чинь дагуу хийгддэг бөгөөд дааж давшгүй ямар ч ачааг та нарт өгдөггүй. Үүнийг чи одоо тодорхой мэддэггүй бөгөөд Би чамд хатуу хандаж байгаа мэт санагддаг, үнэндээ чамайг өдөр бүр гэсгээж, шүүж, зэмлэдгийн шалтгаан нь Би чамайг үзэн яддагаас болдог гэж чи үргэлж итгэдэг. Гэхдээ чиний амсдаг зүйл гэсгээлт, шүүлт мөн хэдий ч энэ нь үнэндээ чамайг гэх хайр, хамгийн агуу хамгаалалт билээ. Хэрвээ чи энэ ажлын илүү гүн гүнзгий утга учрыг ухаарч чадахгүй бол чиний хувьд үргэлжлүүлэн туулах боломжгүй болно. Энэхүү аврал чамд тайтгарал авчрах ёстой. Ойлгож ухамсарлахаас бүү татгалз. Өдий хүрсэн болохоор чи байлдан дагуулалтын ажлын ач холбогдлыг тодорхой ойлгосон байх ёстой бөгөөд энэ талаар янз бүрийн үзэл бодол өвөрлөх ёсгүй!

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 6

Өнөөдөр, Петрт байсан эрүүл ухаанд хүрэх нь бүү хэл, олон хүн Паулын эрүүл ухаанд ч хүрч чаддаггүй. Тэдэнд бүр Паулын ухамсар ч байдаггүй. Эзэн Есүсийг хяхан хавчсанаас нь болоод Паулыг Эзэн цохисон хэдий ч хожим нь тэрээр Эзэний төлөө ажиллаж, зовох шийдвэртэй болсон юм. Есүс түүнд өвчин өгсөн ба хожим нь Паул ажиллаж эхэлмэгцээ энэ өвчнөөс болж зовсоор байв. Өөрийнх нь биед өргөс байна гэж яагаад тэр хэлсэн бэ? Өргөс нь үнэндээ өвчин байсан бөгөөд Паулын хувьд энэ нь аюулт сул тал байв. Тэр хэчнээн их ажил хийсэн ч, эсвэл зовох шийдвэр нь хэчнээн их байсан ч, тэрхүү өргөснөөс салж чадаагүй юм. Гэсэн ч, Паул өнөөдрийн хүмүүс та нараас хавьгүй илүү сайн хэв чанартай байсан бөгөөд бас ухамсартай, та нараас ч илүү эрүүл ухаантай байлаа. Есүсээр цохиулсныхаа дараа Паул Есүсийн шавь нарыг хяхан хавчихаа больж, Есүсийн төлөө номлож, зовж эхэлжээ. Тэгвэл зовлон туулахад түүнийг юу зоригжуулсан бэ? Их гэрлийг харсан болохоор Эзэн Есүст гэрчлэл хийх ёстой ба Есүсийн шавь нарыг цаашид хяхан хавчиж, Бурханы ажлыг цаашид эсэргүүцэх ёсгүй гэж Паул итгэсэн юм. Паул шашны өндөр албан тушаалтнуудын нэг байв. Тэрээр маш их мэдлэгтэй, авьяастай байсан бөгөөд жирийн хүмүүсийг дорд үздэг, ихэнх хүмүүсээс илүү хүчирхэг зан төлөвтэй байлаа. Гэхдээ “их гэрэл” өөр дээр нь туссаны дараа тэрээр

Эзэн Есүсийн төлөө ажиллаж, Бурханы төлөө зовох шийдвэр гаргаж, өөрийгөө Бурханд өргөн барьж чадсан нь эрүүл ухаантай гэдгийг нь нотолсон юм. Есүсийн шавь нарыг хяхан хавчиж, баривчилж байх үед нь Есүс түүнд үзэгдэж: “Паул аа, чи яагаад Намайг хяхан хавчдаг юм бэ?” гэсэн. Паул тэр даруй газар унаж: “Та хэн бэ, Эзэн минь?” гэжээ. Тэнгэрээс дуу гарч: “Би бол чиний хяхан хавчдаг Есүс мөн” гэж хэлсэн юм. Гэнэт л Паул сэрсэн ба тэр үед л тэрээр Есүс бол Христ, Бурхан мөн гэдгийг мэджээ. “Би дуулгавартай байх ёстой. Бурхан надад энэхүү нигүүлслийг өгсөн—би Түүнийг ингэж хяхан хавчсан ч Тэр намайг цохиогүй, мөн намайг хараагаагүй. Би Түүний төлөө зовох ёстой.” Паул, Эзэн Есүс Христийг хяхан хавчиж байгаад, одоо Түүний шавь нарыг хөнөөж байгаагаа, мөн Бурхан өөрийг нь хараагаагүй, харин түүн дээр гэрэл тусгасныг ухаарсан юм. Энэ нь түүнийг зоригжуулсан бөгөөд тэрээр: “Хэдийгээр би Түүний царайг хараагүй ч дуу хоолойг нь сонсож, их гэрлийг нь харсан. Бурхан намайг үнэхээр хайрладаг ба Эзэн Есүс Христ бол гарцаагүй хүнийг өршөөж, хүний нүглийг үүрд мөнхөд уучилдаг Бурхан мөн гэдгийг одоо л би үнэнхүү харж байна. Би нүгэлтэн гэдгээ үнэхээр харж байна” гэж хэлжээ. Дараа нь Бурхан Паулын авьяасыг ажилдаа ашигласан хэдий ч үүнийг одоохондоо түр март. Тухайн үеийн түүний шийдвэр, хэвийн хүний эрүүл ухаан, түүний ухамсар—та нар эдгээр зүйлд хүрэх чадваргүй. Өнөөдөр та нар ихээхэн гэрлийг хүлээн аваагүй гэж үү? Бурханы зан чанар бол сүр жавхлан, уур хилэн, шүүлт, гэсгээлтийнх гэдгийг олон хүн хараагүй гэж үү? Хараал, шалгалт, цэвэршүүлэлт хүмүүст олон удаа тохиолдсон—тэгвэл тэд юу сурсан бэ? Чи сахилгажуулалт, харьцалт хүртээд юу олж авсан бэ? Хатуу үгс, цохилт, шүүлт чамд олон удаа тохиолдсон боловч чи тэдгээрт ямар ч анхаарал хандуулдаггүй. Паулд байсан жаахан эрүүл ухаан ч чамд байдаггүй—чи туйлын хоцрогдмол биш гэж үү? Паулын тодорхой харж чаддаггүй зүйл ч бас их байсан. Тэрээр гэрэл өөр дээр нь туссаныг л мэдэж байсан боловч цохигдож унасан гэдгээ мэдээгүй байлаа; гэрэл өөр дээр нь туссаны дараа л тэр Бурханы төлөө өөрийгөө зарлагадаж, Бурханы төлөө зовж, Эзэн Есүс Христэд зориулсан замыг засахын тулд бүхнийг хийж, Эзэнээр золин аврууллахаар илүү олон нүгэлтнийг авчрах ёстой гэдэгтээ итгэсэн юм. Энэ нь түүний шийдвэр, түүний ажлын цорын ганц зорилго байлаа—гэхдээ түүнийг ажиллах үед насан эцэслэх хүртэл нь өвчин түүнийг орхиогүй юм. Паул хорь гаруй жил ажилласан. Тэр ихээхэн зовж, асар их хавчлага, гай зовлон туулсан, гэхдээ мэдээж эдгээр нь Петрийн шалгалтаас хавьгүй бага байв. Хэрвээ та нарт Паулын эрүүл ухаан ч байхгүй бол хэчнээн өрөвдөлтэй вэ? Ийм болохоор Бурхан та нар дээр бүр их ажлыг эхлүүлж яаж чадах юм бэ?

Сайн мэдээ түгээх үедээ Паул асар их тарчлаан амссан. Тухайн үед түүний хийсэн ажил, түүний шийдвэр, итгэл, үнэнч зан, хайр, тэвчээр, даруу байдал болон амьдран харуулсан олон өөр гадаад талын зүйлс нь өнөөдрийн хүмүүс та нараас илүү өндөр байв. Хатуухан хэлбэл, та нарын дотор ямар ч хэвийн эрүүл ухаан байхгүй; та нарт бүр ямар ч мөс чанар, хүн чанар байхгүй. Та нар маш дутуу

дулимаг! Тиймээс та нарын амьдран харуулдаг зүйлд ихэвчлэн ямар ч хэвийн эрүүл ухаан байдаггүй, өөрийн ухамсрын ямар ч тэмдэг байдаггүй. Тухайн үед Паул бие махбодын өвчин туулсан хэдий ч цаг ямагт ийнхүү залбирч, эрж хайсаар байсан: “Энэ өвчин үнэндээ юу юм бэ? Би энэ бүх ажлыг Эзэний төлөө хийсэн, яагаад энэ өвчин шаналал надаас салахгүй байна вэ? Эзэн Есүс намайг туршиж байгаа юм гэж үү? Тэр намайг цохьсон уу? Хэрвээ Тэр намайг цохьсон бол би аль хэдийн үхээд, энэ бүх ажлыг Түүний төлөө хийж чадахгүй байх байсан, мөн ийм их гэрлийг ч хүлээн авахгүй байх байсан. Тэр бас миний шийдвэрийг биелүүлсэн.” Энэ өвчин бол Бурхан өөрийг нь туршиж байгаа хэрэг, энэ нь өөрийнх нь итгэл, сэтгэлийн тэнхээг батжуулж байгаа гэж Паулд үргэлж санагддаг байсан—Паул үүнийг ингэж харсан юм. Чухамдаа түүний өвчин нь Эзэн Есүс түүнийг цохисноос үүдсэн үр дагавар байв. Энэ нь түүнийг сэтгэл санааны дарамтад оруулж, тэрслүү байдлыг нь хазаарласан юм. Хэрвээ та нар Паулын орчин нөхцөлд байгаагаа мэдвэл яах байсан бэ? Зовох шийдвэр болон чадвар чинь Паулынхтай адил байж чадах уу? Өнөөдөр та нар өвчин тусах юм уу асар их шалгалт туулж, зовох болбол ямар байхыг чинь хэн мэдэх билээ. Хэрвээ та нарыг шувууны торонд хориод, байнга хооллох юм бол та нар зүгээр байна. Эс бөгөөс та нар яг л чоно шиг, ямар ч хүн чанаргүй байх болно. Иймээс бага зэргийн хязгаарлалт, зовлон бэрхшээл туулах нь та нарын хувьд сайн хэрэг; хэрвээ та нарыг амар тайван байлгавал та нар сүйрнэ, тэгвэл та нар яаж хамгаалагдаж чадах юм бэ? Өнөөдөр та нар гэсгээгдэж, шүүгдэж, хараагддаг учраас л хамгаалагддаг. Ихээхэн зовсон учраас л хамгаалагддаг. Хэрвээ тэгээгүй бол та нар аль хэдийн доройтолд орох байсан. Энэ нь та нарт зориуд хүндрэл учруулж байгаа хэрэг биш—хүний уг чанарыг өөрчлөхөд хэцүү байдаг бөгөөд хүмүүсийн зан чанарыг өөрчлөхийн тулд ингэх ёстой юм. Өнөөдөр та нарт Паулын мөс чанар, эрүүл ухаан ч байдаггүй, түүний ухамсар ч байдаггүй. Та нарыг үргэлж дарамталж байх ёстой бөгөөд сүнсийг чинь сэрээхийн тулд үргэлж гэсгээж, шүүж байх ёстой. Гэсгээлт, шүүлт бол та нарын аминд хамгийн ашиг тустай зүйл юм. Шаардлагатай үед бас баримтуудын ирэлтийн гэсгээлт байх ёстой; тэр үед л та нар бүрэн захирагдана. Гэсгээлт, хараалгүйгээр толгой бөхийх дургүй, захирагдах дургүй тийм уг чанар та нарт байдаг. Нүдний чинь өмнөх баримтгүйгээр ямар ч үр нөлөө байхгүй байх болно. Та нарын ёс жудаг хэтэрхий дорд агаад үнэ цэнгүй! Гэсгээлт, шүүлтгүйгээр та нарыг байлдан дагуулах хэцүү бөгөөд шударга бус, дуулгаваргүй байдлыг чинь дарахад бэрх байх болно. Хуучин уг чанар чинь маш гүн үндэслэсэн байдаг. Хэрвээ та нарыг сэнтий дээр тавих юм бол та нар орчлон ертөнц дэх өөрийн байрыг мэдэхгүй, тэр ч бүү хэл хаашаа чиглэн явж байгаагаа ч мэдэхгүй. Та нар бүр хаанаас ирснээ ч мэдэхгүй юм чинь бүтээлийн Эзэнийг яаж мэдэх юм бэ? Өнөөдрийн цагаа олсон гэсгээлт, хараалгүйгээр сүүлчийн өдрүүд чинь аль хэдийн ирчихсэн байх байлаа. Та нарын хувь заяаны талаар ярихын ч хэрэггүй—бүр ч их аюул заналхийлж байгаа бус уу? Цагаа олсон энэхүү гэсгээлт, шүүлтгүйгээр та нар хэчнээн их биеэ тоож, хэр их

доройтохыг хэн мэдэх билээ. Энэ гэсгээлт, шүүлт та нарыг өдий хүргэсэн ба амьдралыг чинь хадгалсан. Хэрвээ та нарыг “эцгийнхтэй” чинь адилхан арга барил хэрэглэн “сургаж боловсруулсан” бол ямар ертөнцөд орох байсныг чинь хэн мэдэх билээ! Та нарт өөрсдийгөө хянах, эргэцүүлэх ямар ч чадвар байхгүй. Та нар шиг хүмүүсийн хувьд, ямар нэг саад бэрхшээл, үймээн самуун учруулалгүй, зүгээр л дагаж, дуулгавартай байвал Миний зорилго биелнэ. Та нар өнөөдрийн гэсгээлт, шүүлтийг илүү сайн хүлээн авах ёстой бус уу? Та нарт өөр ямар сонголт байгаа юм бэ? Паул Эзэн Есүсийн үг хэлж, ажиллаж байгааг харах үедээ мөн л итгээгүй. Хожим нь, Эзэн Есүсийг загалмайд цовдлогдоод, дахин амилсны дараа тэр энэ баримтыг мэдсэн атлаа үргэлжлүүлэн хяхан хавчиж, эсэргүүцсэн. Энэ нь санаатайгаар нүгэл үйлдэх гэсэн үг бөгөөд иймээс түүнийг цохижээ. Анх тэрээр, Есүс гэж нэрлэгддэг Хаан иудейчүүдийн дунд байгаа гэдгийг мэдэж байсан, тэр үүнийг сонссон байсан юм. Дараа нь сүмд номлол айлдаж, газар нутаг даяар тунхаглаж байхдаа тэр Есүсийн эсрэг явж, ямар нэг хүнийг дуулгавартай дагахаас ихэмсгээр татгалзсан. Эдгээр зүйл тухайн үеийн ажилд үлэмж их саад болсон билээ. Есүсийг ажиллаж байх үед Паул хүмүүсийг шууд хяхан хавчиж, баривчлаагүй боловч Есүсийн ажлыг нураахын тулд номлол болон үг ашиглаж байсан. Хожим нь Эзэн Есүс Христийг загалмайд цовдлогдсоны дараа тэрээр шавь нарыг нь баривчилж эхэлсэн ба нэг газраас нөгөө рүү яаравчлан, тэднийг хавчихын тулд чадах бүхнээ хийдэг байв. “Гэрэл” өөр дээр нь туссаны дараа л тэр сэрж, асар их харуусыг мэдэрчээ. Түүнийг цохиулсны дараа өвчин нь хэзээ ч түүнээс салаагүй юм. Заримдаа өвчин хууч нь улам дордож байгаа мэт түүнд санагдаж, орноосоо ч босож чаддаггүй байжээ. Тэрээр: “Юу болоод байна аа? Намайг үнэхээр цохисон юм гэж үү?” хэмээн бодсон. Уг өвчин түүнийг хэзээ ч орхиогүй бөгөөд энэхүү өвчний улмаас тэр ихээхэн ажил хийсэн юм. Түүний биеэ тоосон, дур зоргоороо байдлын улмаас Есүс энэ өвчнийг Паулд оруулсан гэж хэлж болно; энэ нь Паулын шийтгэл байсан боловч Бурханы ажлыг өргөжүүлэх гэсэндээ Паулын авьяасыг Бурханы ажилд ашиглахын тулд ч бас үүнийг хийсэн юм. Үнэн хэрэгтээ Бурханы санаа зорилго нь Паулыг аврах биш, харин түүнийг ашиглах явдал байлаа. Гэсэн ч Паулын зан чанар хэтэрхий ихэрхүү, дур зоргоороо байсан болохоор түүний биед “өргөс” оруулжээ. Эцэст нь, Паулыг ажлаа дуусгах үед түүний хувьд өвчин нь тийм ч их шаналгаатай байхаа больсон бөгөөд тэрээр: “Би сайн тэмцлээр тэмцэж, явах замаа дуусгаж, итгэлээ хадгалсан: Одооноос эхлээд надад зориулсан зөвт байдлын титэм зэхэгджээ” гэх үгийг хэлж чадсан юм—тэр Бурханы ажлыг мэдээгүй учраас ингэж хэлжээ. Та нарын дунд Паул шиг хүн олон байгаа боловч замын төгсгөл хүртэл дагах шийдвэр үнэхээр байгаа бол та нарт зохисгүй хандахгүй. Паул хэрхэн тэрсэлж, эсэргүүцэж байсныг бид энд хэлэлцэхгүй; харин эерэг, магтууштай талыг нь үргэлжлүүлэн ярьцгаая: Тэр мөс чанартай байсан ба “гэрлийг” нэг удаа хүлээн авсныхаа дараа өөрийгөө Бурханд зориулж, Бурханы төлөө зовж чадсан. Энэ нь түүний давуу тал байв. Түүнд давуу

тал байсан учраас тэр бол ерөөгдсөн хүн байсан гэж итгэдэг хүмүүс байгаа бол, мөн тэр гэсгээгдэх албагүй гэж бодож байгаа бол эдгээр нь эрүүл ухаангүй хүмүүсийн үг юм.

Залбирч, Бурханы үгийг уншиж байхдаа олон хүн Бурханд захирагдахыг хүсэж байна гэж хэлдэг ч дараа нь далдуур замбараагүй болдог ба энэ тухай юу ч боддоггүй. Бурханы үг ахин дахин хэлэгдэж, давхарга давхаргаар нь илчилдэг ба хүмүүсийн хамгийн доод давхаргыг илчлэх үед л тэд “амар тайвныг олж”, ихэрхүү, эрх дураараа, дээрэнгүй аашлахаа больдог. Өнөөдрийн байр байдал чинь ийм байгаа болохоор, амсхийх боломж олгохгүйн тулд та нарыг хайр найргүйгээр цохиж, илчилж, нарийвчлан шүүх ёстой. Та нарын хувьд, хатуу гэсгээлт, шүүлт та нарыг орхихгүй, яллалт, хараал та нараас холдохгүй байж, Бурханы захиргааны зарлигийн гар хэзээ ч та нараас салахгүй гэдгийг харуулсан нь дээр. Яг л Хуулийн эрин үед, Ехова хэзээ ч өөрийг нь орхиогүйг Аарон харсантай адил (түүний харсан зүйл нь Еховагийн байнгын удирдамж, хамгаалалт байсан; өнөөдөр та нарын хардаг Бурханы удирдамж бол гэсгээлт, хараал болон шүүлт юм) бөгөөд өнөөдөр Еховагийн захиргааны зарлигийн гар та нарыг ч бас орхидоггүй. Гэхдээ, та нарын тайвширч болох нэг зүйл бий: Та нар яаж ч эсэргүүцэж, тэрсэлж, шүүлт хийх нь хамаагүй, та нарын махан биед ямар ч хор хөнөөл учрахгүй. Гэхдээ эсэргүүцэл нь дэндэж, ажилд саад болдог хүмүүс байвал энэ нь хүлээн зөвшөөрөх аргагүй юм; үүнд хязгаар бий. Чуулганы амьдралд бүү саад бол, бүү үймүүл, Ариун Сүнсний ажилд бүү саад бол. Бусад зүйлийн тухайд чи юу хүссэнээ хийж болно. Чи, амийг эрэлхийлэхийг хүсдэггүй бөгөөд дэлхий ертөнц рүү буцахыг хүсэж байна гэж хэлбэл бушуухан яв! Та нар Бурханы ажилд саад хийхгүй байгаа цагт хүссэн бүхнээ хийж болно. Гэсэн ч чиний мэдэх ёстой дахиад нэг зүйл бий: Эцэст нь тийм дур зоргоороо нүгэлтнүүд таягдан хаягдах болно. Өнөөдөр чамайг зэмлэхгүй байж болох боловч эцэст нь хэсэгхэн хүмүүс л гэрчлэл хийж чадна—бусад нь бүгд аюулд өртөнө. Хэрвээ чи энэ урсгалд байхыг хүсэхгүй байгаа бол тэр чинь зүгээр. Өнөөдрийн хүмүүст тэвчээртэй хандаж байгаа; чи маргаашийн гэсгээлтээс айхгүй байгаа тохиолдолд Би чамайг хязгаарладаггүй. Гэхдээ хэрвээ энэ урсгалд байгаа бол чи гэрчлэл хийж, гэсгээгдэх ёстой. Хэрвээ чи үүнээс татгалзаж, дэлхий ертөнц рүү буцахыг хүсвэл тэр нь зүгээр—хэн ч чамайг зогсоохгүй! Гэхдээ, хэрвээ чи Бурханы ажлыг сүйтгэж, үймүүлдэг ажил хийдэг бол тэрний чинь төлөө чамайг яасан ч уучилж болохгүй! Ямар хүмүүс гэсгээгдэж, хэний гэр бүл хараагддаг талаар нүд чинь юу харж, чих чинь юу сонсдог тухайд бол—энэ бүхэнд хил хязгаар, зааг бий. Ариун Сүнс аливааг хөнгөхнөөр хийдэггүй. Үйлдсэн бүхэнд чинь үндэслэн, шударга бус байдлын чинь дагуу та нарт хандаж, ноцтойгоор авч үзсэн бол та нараас хэн чинь амьд үлдэж чадах юм бэ? Та нар бүгд гай гамшиг туулах байсан ба нэг нь ч сайн үр дүнтэй байхгүй байсан. Гэсэн ч өнөөдөр олон хүнд тэвчээртэй ханддаг. Хэдий та нар шүүж, тэрсэлж, эсэргүүцдэг ч саад болохгүй л байгаа бол Би та нар луу инээмсэглэн харна. Хэрвээ та нар үнэхээр амийг эрэлхийлдэг бол бага

зэргийн гэсгээлт туулах ёстой бөгөөд хагалгаа хийлгэхээр мэс заслын ширээн дээр гарахдаа хайртай зүйлсээсээ хагацахын шаналлыг тэвчих ёстой; Петр шалгалт болон зовлонг хүлээн зөвшөөрсөн шиг чи шаналлыг тэвчих ёстой. Өнөөдөр та нар шүүх суудлын өмнө байна. Ирээдүйд та нар “толгой цавчигч машинд” орох ёстой ба тэр нь өөрсдийгөө “золиослох” үе байх болно.

Эцсийн өдрүүд дэх ажлын сүүлчийн энэ үе шатны үеэр, Бурхан махан биеийг чинь устгахгүй гэж чи итгэж байж магадгүй бөгөөд Түүнийг эсэргүүцэж, шүүдэг ч гэсэн чамд ямар нэгэн өвчин тусахгүй байж магад гэж хэлж болох юм—гэхдээ Бурханы хатуу ширүүн үгс чам дээр ирэх үед, мөн тэрслүү байдал, эсэргүүцэл, муу муухай төрх чинь бүгд ил болох үед чи нуугдаж чадахгүй. Тэгээд сандарч цочирдон, яахаа мэдэхгүй байх болно. Өнөөдөр та нар бага зэргийн мөс чанартай байх ёстой. Бурханыг эсэргүүцэж, Түүний эсрэг тэрсэлдэг муу ёрын нэгний дүрд бүү тогло. Чи өөрийн хуучин өвөг дээдсээсээ нүүр буруулах ёстой; энэ бол чамд байх ёстой биеийн хэмжээ, чиний эзэмших учиртай хүн чанар юм. Чи өөрийн хэтийн ирээдүйг, эсвэл өнөөдрийн таашаалыг хойш тавьж хэзээ ч чаддаггүй. “Та нар Намайг дагаж, үнэнийг эрэлхийлэхийн тулд чадах бүхнээ хийж байгаа цагт Би та нарыг гарцаагүй төгс болгоно. Төгс болгуулмагцаа та нар сайхан хүрэх газартай байх болно—Надтай хамт ерөөл эдлэхийн тулд та нар Миний хаанчлал руу хүргэгдэнэ” гэж Бурхан хэлдэг. Үзэсгэлэнтэй сайхан хүрэх газрыг амласан ч гэсэн та нарт тавих шаардлагыг хэзээ ч багасгаж болохгүй. Бас нэг болзол бий: Та нар байлдан дагуулагдаж, эсвэл төгс болгуулж байх нь хамаагүй, өнөөдөр зарим нэг гэсгээлт, зовлон туулах ёстой; та нар цохиулж, сахилгажуулагдах ёстой; Миний үгийг сонсож, Миний замыг дагаж, Бурханы хүслийг биелүүлэх ёстой—энэ бол хүмүүс та нарын хийх ёстой зүйл билээ. Хэрхэн эрэлхийлэхээс үл хамааран чи энэ замыг тодорхой сонсох ёстой. Хэрвээ чи үнэхээр жинхэнээсээ ойлгосон бол үргэлжлүүлэн дагаж чадна. Энд ямар ч хэтийн ирээдүй, итгэл найдвар байхгүй гэж итгэж байгаа бол чи явж болно. Эдгээр үгийг та нарт тодорхой хэлсэн боловч хэрвээ чи үнэхээр явахыг хүсэж байгаа бол өчүүхэн төдий ч мөс чанаргүй гэдгийг чинь л энэ нь харуулдаг; чи бол чөтгөр гэдгийг батлахад энэ үйлдэл чинь хангалттай. Хэдий чи бүхнийг Бурханы зохион байгуулалтад орхидог гэж хэлдэг боловч махан бие болон амьдран харуулдаг зүйлд чинь үндэслэвэл чи Сатаны эзэмшил дор амьдарсаар байдаг. Хэдийгээр Сатан ч бас Бурханы гарт байдаг боловч чи өөрөө Сатанд харьяалагддаг хэвээр бөгөөд Бурханаар хараахан үнэхээр аврууллаагүй байгаа, учир нь чи Сатаны нөлөөн доор амьдарсаар байгаа билээ. Аврагдахын тулд чи хэрхэн эрэлхийлэх ёстой вэ? Сонголт чинийх—явах ёстой замаа чи сонгох хэрэгтэй. Эцэстээ чи: “Надад илүү дээр зүйл юу ч үгүй, би Бурханы хайрыг мөс чанарааараа хариулж, жаахан хүн чанартай байх ёстой. Би илүү агуу юунд ч хүрч чадахгүй, хэв чанар минь ч тийм өндөр биш; би Бурханы ажлын үзэгдлийг ч, утга учрыг ч ойлгодоггүй. Би ердөө Бурханы хайрыг хариулж, Бурханы шаарддаг болгоныг хийж, чадах бүхнээ хийдэг. Тэгээд Бурханы бүтээлийн хувиар үүргээ

биелүүлдэг” гэж хэлж чадах юм бол Би баярлана. Энэ бол чиний хийж чадах хамгийн өндөр дээд гэрчлэл юм. Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэх гэдэг нь нэг хэсэг хүмүүсээс шаарддаг хамгийн өндөр стандарт юм. Чи чадлынхаа хэрээр л хий; чамд тавьдаг шаардлага тийм ч өндөр биш. Чадах бүхнээ хийж байгаа цагт тэр чинь л чиний гэрчлэл мөн.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 7

Та нарын хүн чанар хэтэрхий дутуу дулимаг, амьдралын хэв маяг чинь хэтэрхий дорд, доройтмол бөгөөд та нар ямар ч хүн чанаргүй, мэдлэг ухаанаар дутмаг. Тийм учраас хэвийн хүн чанарын зүйлсээр өөрсдийгөө зэвсэглэх хэрэгтэй. Мөс чанар, эрүүл ухаан, мэдлэг ухаантай байх; аливааг яаж ярьж, хэрхэн харахаа мэдэх; цэвэр байдалд анхаарал хандуулах; хэвийн хүн шиг үйлдэх—энэ нь бүгд хэвийн хүн чанарын мэдлэгийн онцлог юм. Эдгээр зүйл дээр зүй зохистой авирлах үед та нарыг боломжийн хүн чанартай гэж тооцдог. Та нар бас сүнслэг амьдралын төлөө өөрсдийгөө зэвсэглэх ёстой. Газар дээрх Бурханы бүхий л ажлыг мэдэж, Түүний үгийг туулах ёстой. Түүний зохицуулалтыг хэрхэн дуулгавартай дагаж, бүтээгдсэн зүйлийн үүргийг хэрхэн биелүүлэхээ мэдэх ёстой. Эдгээр нь өнөөдөр чиний орох ёстой хоёр тал буюу хүн чанартай амьдралын төлөө өөрийгөө зэвсэглэх, сүнслэг амьдралын төлөө хэрэгжүүлэх явдал бөгөөд хоёулаа зайлшгүй шаардлагатай.

Зарим хүн утгагүй бөгөөд өөрсдийгөө хүн чанарын онцлогоор зэвсэглэхээ л мэддэг. Тэдний гадаад төрхөөс ямар ч өө олох аргагүй; хэлдэг зүйл, ярьж байгаа байдал нь зохистой байдаг ба хувцаслалт нь дэгжин, зүй зохистой байдаг. Гэхдээ тэд дотроо хоосон байдаг; гаднаа л хэвийн хүн чанар эзэмшсэн мэт санагддаг. Юу идэх, юу өмсөх, юу хэлэхдээ л анхаардаг зарим хүн бий. Бүр шал шүүрдэх, ор засах, цэвэрлэгээ хийх зэрэг зүйлд онцгойлон анхаардаг хүмүүс ч байдаг. Тэд энэ бүх зүйлд сайн дадсан байж болох боловч Бурханы эцсийн өдрүүдийн ажлын талаарх, эсвэл шүүлт, гэсгээлт, цэвэршүүлэлт, шалгалтын талаарх мэдлэгийнхээ тухай ярихыг хүсэх үед чинь өчүүхэн төдий ч туршлага харуулахгүй байж магадгүй. Чи тэднээс ингэж асууж болох юм: “Бурханы газар дээрх үндсэн ажлыг чи ойлгодог уу? Өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы ажил Есүсийн ажлаас юугаараа ялгаатай вэ? Еховагийн ажлаас юугаараа ялгаатай вэ? Тэд нэг Бурхан мөн үү? Тэр энэ эрин үеийг төгсгөхөөр ирсэн үү, эсвэл хүн төрөлхтнийг аврахаар ирсэн үү?” Гэвч ийм хүмүүст эдгээр асуудлын талаар хэлэх зүйл юу ч байдаггүй. Зарим нь гагцхүү гаднаа сайхан гоёдог: Эгч нар өөрсдийгөө цэцэг мэт хөөрхнөөр гоёж гооддог ба ах нар ханхүү юм уу залуухан баян дэгжин эр шиг хувцасладаг. Тэд өөрсдийн иддэг, өмсдөг зүйлс гэх мэт гадаад талын зүйлсийг л анхаардаг; дотроо ядуу зүдүү байдаг ба Бурханы талаар өчүүхэн ч мэддэггүй. Үүнд ямар утга учир байх юм бэ? Мөн ядуу гуйлгачин шиг хувцасладаг зарим хүн байдаг ба Зүүн Азийн

боолуудтай үнэхээр адилхан харагддаг! Та нараас Миний шаарддаг зүйлийг та нар үнэхээр ойлгодоггүй гэж үү? Өөр хоорондоо ярилцацгаа: Та нар үнэндээ юу олж авсан бэ? Та нар ийм олон жил Бурханд итгэсэн ч хураасан бүхэн чинь энэ—санаа зовохгүй байна уу? Ичихгүй байна уу? Та нар энэ олон жилд үнэн замыг эрэлхийлсээр ирсэн ч өнөөдөр биеийн хэмжээ чинь бор шувууныхаас ч жаахан хэвээр байдаг! Та нарын дундах, хувцаслалт, будаг шунхаараа зураг шиг хөөрхөн бүсгүйчүүд өөрсдийгөө нэг нэгэнтэйгээ харьцуулж байгааг хар—та нар юу харьцуулдаг юм бэ? Зугаа цэнгэлээ юу? Шаардлагуудаа юу? Намайг загвар өмсөгчдийг элсүүлэхээр ирсэн гэж та нар бодож байна уу? Ямар ичгүүр сонжуургүй юм бэ! Та нарын амь хаана байна вэ? Эрэлхийлдэг зүйл чинь та нарын хэмжээ хязгааргүй их хүсэл биш гэж үү? Чи өөрийгөө маш үзэсгэлэнтэй гэж боддог, гэхдээ чи гоё сайхан хувцасладаг байж болох ч үнэн хэрэгтээ овоолсон өтөг баасан дунд төрсөн мурилзсан өт биш гэж үү? Өнөөдөр энэ тэнгэрлэг ерөөлийг эдлэх хувьтай байгаа чинь хөөрхөн царайнаас чинь болоогүй, харин Бурхан чамайг онцгойлон өргөснөөс болж байгаа юм. Чи хаанаас ирсэн тухайгаа одоо ч тодорхой мэдэхгүй байна уу? Амийн талаар дурдангуут чи амаа хамхиад, юу ч хэлэлгүй, хөшөө шиг чимээгүй байдаг ч гоёж гоодох зориг зүрхтэй хэвээр байдаг! Нүүрэндээ оо энгэсэг түрхэх сонирхолтой хэвээр л байдаг! Бас өөрсдийнхөө дундах дэгжин залуусыг буюу нүүрэндээ хайхрамжгүй илэрхийлэл гарган дэггүйтэж, зорилгогүй хэсүүчлэн бүхэл өдрийг өнгөрүүлдэг дур зоргоороо эрсийг хар. Хүн ингэж авирлах ёстой юм уу? Та нарын дундах хүн нэг бүр, эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай өөрсдийнхөө анхаарлыг бүхий л өдөржингөө юунд зориулдаг вэ? Та нар хэнд найдаж амь зуудгаа мэдэх үү? Өөрийнхөө хувцсыг хар, гартаа юу олж авснаа хар, гэдсээ ил—энэ олон жилийн турш итгэхдээ төлсөн хөлс, цусныхаа төлөөсөнд чи ямар ашиг тус хүртсэн бэ? Чи дурсгалт газруудыг үзэх талаар бодсоор байдаг, өмхий биеэ гоёх тухай бодсоор байдаг—үнэ цэнгүй эрэл хайгуул! Чамаас хэвийн хүн бай гэж шаарддаг атал өнөөдөр чи хэвийн бус байгаад зогсохгүй гажуудсан байдаг. Ийм хүн яаж Миний өмнө ирэх зориг зүрхтэй байж чадах юм бэ? Ийм хүн чанартайгаар сэтгэл татам байдлаа харуулж, махан биеэ гайхуулж, үргэлж махан биеийн шунал тачаал дотор амьдарч байгаа чи бузар чөтгөр болон муу ёрын сүнсний үр удам биш гэж үү? Тийм бузар чөтгөрт удаан оршин тогтнохыг Би зөвшөөрөхгүй! Зүрх сэтгэлдээ юу боддогийг чинь Намайг мэдэхгүй гэж бүү бод. Чи шунал тачаал болон махан биеэ хатуу чанд хазаарлаж болох боловч зүрх сэтгэлдээ өвөрлөдөг бодлыг чинь Би яаж мэдэхгүй байх билээ? Нүдээрээ хүсэмжилдэг бүхнийг чинь Би яаж мэдэхгүй байх билээ? Залуу бүсгүйчүүд та нар махан биеэ харуулахын тулд өөрсдийгөө тун хөөрхөн болгодог бус уу? Та нарын хувьд эрэгтэйчүүд ямар ашигтай юм бэ? Тэд та нарыг зовлон шаналлын далайгаас үнэхээр аварч чадна гэж үү? Та нарын дундах дэгжин залуус бүгд өөрсдийгөө боловсон, гоё ганган харагдуулахаар хувцасладаг боловч энэ нь “хээнцэр” зүс царайдаа анхаарал татах зорилготой башир заль бус уу? Та нар хэний төлөө үүнийг хийж байгаа юм бэ? Та

нарын хувьд эмэгтэйчүүд ямар ашигтай юм бэ? Тэд нүглийн чинь эх сурвалж биш гэж үү? Эрчүүд, эмэгтэйчүүд та нарт Би олон үг хэлсэн атал та нар цөөхнийг нь л мөрддөг. Тэгээд чих чинь хатуурч, хараа чинь муудаад, биед чинь шунал тачаалаас өөр юу ч байхгүй болох хүртлээ зүрх сэтгэл чинь цэвдэг болсон, ийм болохоор та нар зугтаж чадалгүйгээр, үүнд урхидуулсан. Бузар буртаг, хөө тортог дотор мурилздаг өтнүүд та нарт хэн ойртон очихыг хүсэх юм бэ? Та нар бол овоолсон өтөг баасан дотроос Миний өргөсөн хүмүүсээс цаашгүй бөгөөд анхнаасаа та нарт хэвийн хүн чанар байгаагүй гэдгийг бүү март. Та нараас Миний шаарддаг зүйл бол анхнаасаа та нарт байгаагүй хэвийн хүн чанар болохоос, шунал тачаалаа харуулж, маш олон жилийн турш диаволын сургасан илжирсэн махан биеэ дураар нь тавих явдал биш. Та нар ингэж хувцаслах үедээ бүр илүү гүн урхидуулна гэдгээс айхгүй байна уу? Та нар анхнаасаа нүгэлтэй гэдгээ мэдэхгүй гэж үү? Бие чинь шунал тачаалаар маш их дүүрсэн болохоор энэ нь бүр хувцаснаас чинь нэвчин гарч, тэвчихийн аргагүй муухай, бузар чөтгөр шиг байдлыг чинь илчилдэг гэдгийг мэдэхгүй гэж үү? Үүнийг та нар хэнээс ч илүү тодорхой мэддэг биш гэж үү? Та нарын зүрх сэтгэл, нүд, уруул бүгд бузар чөтгөрөөр бузарлагдсан бус уу? Энэ хэсгүүд чинь бузар биш гэж үү? Ямар нэг юм хийхгүй байгаа цагт хамгийн ариун нь гэж чи өөрийгөө боддог уу? Сайхан хувцаслах нь та нарын булай сэтгэлийг нууж чадна гэж боддог уу? Тэгэх боломжгүй! Би та нарт илүү бодитой байхыг зөвлөж байна: Заль мэхтэй, хуурмаг бүү бай, өөрсдийгөө бүү гайхуул. Та нар шунал тачаалаа нэг нэгэндээ гайхуулдаг боловч хариуд нь хүртэх бүхэн чинь үүрд мөнхийн зовлон, өршөөлгүй цээрлүүлэлт юм! Нэг нэгэнтэйгээ аальгүйтэж, дурлалцах та нарт ямар хэрэгтэй юм бэ? Энэ нь та нарын ёс жудаг уу, шулуун шударга зангийн чинь хэр хэмжээ юү? Та нарын дунд байгаа хар дом, хар шидэд оролцдог хүмүүсийг Би үзэн яддаг; та нарын дундах махан биеэ хайрладаг залуусыг үзэн яддаг. Та нар биеэ барьсан нь дээр, учир нь одоо Би та нараас хэвийн хүн чанартай байхыг, шунал тачаалаа харуулахгүй байхыг шаарддаг—гэсэн ч махан бие чинь хэтэрхий элбэг, шунал тачаал чинь дэндүү их учраас та нар ашиглаж болох боломж бүрийг ашигладаг!

Гаднаа хүн чанарын амьдрал чинь нэлээд цэгцтэй байдаг боловч амийн талаарх мэдлэгээ ярихыг хүсэх үед чамд хэлэх юм юу ч байдаггүй; энэ тухайд бол чи үгээгүй хоосон юм. Чи өөрийгөө үнэнээр зэвсэглэх ёстой! Хүн чанарын амьдрал чинь илүү дээрдсэн тул доторх амь чинь ч бас өөрчлөгдөх ёстой; өөрийнхөө бодлыг, Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлыг өөрчил, мөн доторх мэдлэг болон сэтгэлгээгээ, өөрийн үзэл доторх Бурханы талаарх мэдлэгийг өөрчил. Харьцалт, илчлэл, хангалтаар дамжуулан өөрийнхөө талаарх, хүний амьдрал, Бурханд итгэх итгэлийн талаарх мэдлэгээ аажмаар өөрчил; өөрийнхөө ойлголтыг цэвэр байлга. Ийм маягаар хүний доторх бодол өөрчлөгдөж, аливааг харах байдал болон оюун санааны төлөв нь өөрчлөгддөг. Үүнийг л амь зан чанарын өөрчлөлт гэж болно. Бүхэл өдөржингөө Бурханы үгийг унших юм уу угаалга, цэвэрлэгээ хийж өнгөрүүлэхийг чамаас шаардаагүй. Хэвийн хүн чанарын амьдрал ядаж л угаасаа

тэсэж болмоор байх ёстой. Түүнчлэн, гадаад талын хэрэг явдлыг зохицуулах үедээ бага зэрэг мэдлэг ухаан, эрүүл ухаанаа ашиглах ёстой; гэвч хамгийн чухал зүйл бол амийн үнэнээр зэвсэглэсэн байх явдал юм. Өөрийгөө амиар зэвсэглэх үедээ чи Бурханы үгийг идэж, уухад анхаарах ёстой, мөн Бурханы талаарх мэдлэг, хүний амьдралын талаарх үзэл бодол, ялангуяа эцсийн өдрүүдэд Бурханы хийсэн ажлын талаарх мэдлэгээ ярьж чаддаг байх ёстой. Чи амийг эрэлхийлдэг тул өөрийгөө эдгээр зүйлээр зэвсэглэх ёстой. Бурханы үгийг идэж, уух үедээ өөрийнхөө бодит байр байдлыг тэдгээртэй харьцуулах ёстой. Өөрөөр хэлбэл, бодит туршлагынхаа явцад өөрийнхөө дутагдлыг олж илрүүлэх үедээ чи хэрэгжүүлэх замыг олж, буруу сэдэл болон үзлээ орхих чадвартай байх ёстой. Энэ тухайд чи үргэлж чармайж, эдгээрийг биелүүлэхэд зүрх сэтгэлээ зориулдаг бол дагах замтай байх бөгөөд чамд хоосон санагдахгүй, тийнхүү чи хэвийн байдлаа хадгалж чадна. Тэр үед л чи өөрийнхөө аминд ачаа үүрдэг, итгэлтэй нэгэн байх болно. Бурханы үгийг уншсаныхаа дараа зарим хүн яагаад хэрэгжүүлж чаддаггүй юм бэ? Тэд хамгийн чухал зүйлийг ухаарч чаддаггүйгээс болдог бус уу? Тэд амийг ноцтой авч үздэггүйгээс болдог бус уу? Тэд гол чухал зүйлсийг ухаарч чаддаггүй, хэрэгжүүлэх ямар ч замгүй байдгийн шалтгаан нь Бурханы үгийг унших үедээ тэдгээрийг өөрсдийнхөө байдалтай харьцуулж чаддаггүйгээс, мөн өөрсдийн байр байдлыг захирч чаддаггүйгээс болдог. Зарим хүн: “Би Бурханы үгийг уншаад, өөрийнхөө байдалтай харьцуулсан, бас завхарсан, хэв чанар муутай гэдгээ мэддэг ч Бурханы хүслийг хангалуун байлгах чадваргүй” гэж хэлдэг. Чи хамгийн өнгөц хэсгийг л харсан; махан биеийн зугаа цэнгэлийг хэрхэн хойш тавих, өөрийгөө зөвтгөдгөө хэрхэн болих, өөрийгөө хэрхэн өөрчлөх, эдгээр зүйлд хэрхэн орох, хэв чанараа хэрхэн сайжруулах, аль талаас эхлэх зэрэг чиний мэддэггүй олон бодит зүйл бий. Чи ердөө цөөн хэдэн өнгөцхөн зүйлийг л ухаардаг бөгөөд үнэхээр их завхарсан гэдгээ л мэддэг. Ах эгч нартайгаа уулзах үедээ чи хэр их завхарсан гэдгээ л ярьдаг ба өөрийгөө мэддэг, өөрийнхөө аминд асар их ачаа үүрсэн мэт санагддаг. Үнэндээ завхарсан зан чанар чинь өөрчлөгдөөгүй бөгөөд хэрэгжүүлэх замыг олоогүй гэдгийг чинь энэ нь баталдаг. Хэрвээ чи чуулган удирдаж байгаа бол ах эгч нарын байр байдлыг ойлгож, зааж өгч чаддаг байх ёстой. Ердөө “Хүмүүс та нар дуулгаваргүй, хоцрогдмол юм!” гэж хэлбэл болох уу? Үгүй, чи дуулгаваргүй, хоцрогдмол байдал нь яаж илэрч байгааг онцгойлон хэлэх ёстой. Тэдний дуулгаваргүй байдал, дуулгаваргүй зан авир, сатанлаг зан чанарын талаар ярих ёстой бөгөөд өөрийн үгэн дэх үнэнд тэднийг бүрэн үнэмшүүлэхүйц байдлаар эдгээр зүйлийг ярих ёстой. Санаагаа хэлэхийн тулд баримт болон жишээ ашигла, тэрслүү зан авираас яг яаж ангижирч болох талаар тэдэнд хэлж, хэрэгжүүлэх замыг зааж үзүүл—хүмүүсийг ингэж үнэмшүүлдэг. Ингэдэг хүмүүс л бусдыг удирдах чадвартай; тэд л үнэн-бодит байдлыг эзэмшдэг.

Нөхөрлөлөөр дамжуулан та нарыг одоо олон үнэнээр хангасан бөгөөд чи тэдгээрийг бүртгэх ёстой. Нийт хэчнээн үнэн байгааг нэгтгэн дүгнэж чаддаг байх

ёстой. Хүний эзэмших ёстой хэвийн хүн чанарын хэд хэдэн тал, хүний амь зан чанарын өөрчлөлтийн үндсэн талууд, үзэгдлүүдийн гүнзгийрэл, эрин үеүдийн туршид хүмүүсийн хэрэглэж байсан эндүү ташаа мэдлэг, туршлагыг мэдэж, өөрөө ялган таньж чаддаг болмогцоо л чи зөв замд орно. Шашны хүмүүс Библийг Бурхан мэт шүтдэг; ялангуяа Шинэ Гэрээний Дөрвөн сайн мэдээг Есүсийн дөрвөн өөр нүүр царай мэт үзэж, Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвалын тухай ярьдаг. Энэ бүхэн хамгийн инээдтэй бөгөөд та нар үүнийг нэвт харах ёстой; үүнээс гадна, махбод болсон Бурханы мөн чанар болон эцсийн өдрүүдийн ажлын талаар мэддэг байх ёстой. Түүнчлэн, сүнсэнд амьдрах, Ариун Сүнсээр дүүргэгдэх, юу ч тохиолдсон буулт хийх, эрх мэдэлд захирагдах гэх мэт хэрэгжүүлэлтийн хуучин арга барил, хэрэгжүүлэлттэй холбоотой төөрөгдөл, гажуудлыг чи мэдэж байх ёстой; хүмүүс урьд нь хэрхэн хэрэгжүүлж байсныг болон өнөөдөр хэрхэн хэрэгжүүлэх ёстойг мэдэх хэрэгтэй. Чуулганд удирдагчид болон ажилчид хэрхэн хамтран ажиллах ёстой; өөрийгөө зөвтгөдөг, ихэмсэг зангаа хэрхэн хойш тавих; ах эгч нар бие биетэйгээ хэрхэн хамт амьдрах ёстой; бусад хүмүүс болон Бурхантай хэрхэн хэвийн харилцаа тогтоох; хүний амьдралын хэвийн байдалд хэрхэн хүрэх; сүнслэг амьдралдаа хүмүүс юу эзэмших ёстой; Бурханы үгийг хэрхэн идэж, уух ёстой; Бурханы аль үг мэдлэгтэй холбоотой, аль нь үзэгдэлтэй хамаатай, аль нь хэрэгжүүлэх замтай холбоотой—эдгээрийг бүгдийг нь яриагүй гэж үү? Эдгээр үг нь эрж хайдаг хүмүүст нээлттэй байдаг бөгөөд хэнд ч давуу эрх олгодоггүй. Өнөөдөр та нар хараат байх сэтгэлгээндээ найдалгүй, бие даан амьдрах чадвараа хөгжүүлэх ёстой. Ирээдүйд чамайг залж чиглүүлэх хэн ч байхгүй байх үед чи Миний эдгээр үгийг бодно. Гай зовлонгийн цаг үед, чуулганы амьдралаар амьдрах боломжгүй, ах эгч нар бие биетэйгээ уулзаж чадахгүй, ихэнх нь ганцаараа амьдарч, сайндаа л орон нутгийнхаа хүмүүстэй ярилцаж чаддаг байх үед одоогийн биеийн хэмжээг чинь харгалзан үзвэл та нар ердөө бат зогсож чадахгүй. Гай зовлонгийн дунд бат зогсоход олон хүнд хэцүү байдаг. Амийн замыг мэддэг, хангалттай үнэнээр зэвсэглэсэн хүмүүс л үргэлжлүүлэн ахиц гаргаад, ариусгалт, өөрчлөлтөд аажмаар хүрч чаддаг. Гай зовлон туулах нь амар зүйл биш; хэрвээ чи цөөн хэдэн хоногт л үүнийг туулна гэж боддог бол бодол чинь хэчнээн энгийн болохыг энэ нь нотолдог! Ихээхэн хоосон сургаал ойлгосноор бат зогсож чадна гэж чи боддог ч тийм биш! Хэрвээ чи Бурханы үгэн дэх гол чухал зүйлсийг танин мэддэггүй, үнэний гол онцлогийг ухаарч чаддаггүй, хэрэгжүүлэх замгүй бол цаг нь ирж, ямар нэгэн зүйл чамд тохиолдох үед чи будилна. Сатаны уруу таталтыг ч, цэвэршүүлэлтийн эхлэлийг ч тэсвэрлэж чадахгүй. Хэрвээ чамд ямар ч үнэн байхгүй бөгөөд чи үзэгдэлгүй бол цаг нь ирэх үед нуран унахгүй байж чадахгүй. Чи бүх итгэл найдвараа орхиж, “За яах вэ, би яасан ч үхэх юм бол эцсээ хүртэл гэсгээгдсэн нь бараг дээр! Гэсгээлт ч бай, эсвэл галт нуур руу илгээгдэх ч бай хамаагүй—би юу ч тохиолдсон хүлээн авна!” гэж хэлнэ. Энэ нь үйлчлэл үзүүлэгчдийн цаг үеийнхтэй адилхан: Зарим хүн өөрсдийгөө, яасан ч үйлчлэл үзүүлэгчид мөн гэж итгэсэн тул

амийг эрэлхийлэхээ больсон. Тэд тамхи татаж, архи ууж, махан биеэ өөгшүүлж, юу дуртайгаа хийсэн. Зарим нь зүгээр л дэлхий ертөнц рүү буцсан. Таагүй орчин нөхцөл ч бас ийм байдаг; хэрвээ чи үүнийг даван гарч чадахгүй бол өөрийгөө бага зэрэг зөнд нь орхимогцоо бүх итгэл найдвараа орхино. Хэрвээ чи Сатаны нөлөөллийг даван гарч чадахгүй бол нэг л мэдэхэд Сатанд олзлогдож, дахин нэгэнтээ сүйрэлд автана. Иймээс өнөөдөр чи өөрийгөө үнэнээр зэвсэглэх ёстой; бие даан амьдарч чаддаг байх ёстой; мөн Бурханы үгийг унших үедээ хэрэгжүүлэх замыг хайж чаддаг байх ёстой. Хэрвээ чамайг усалж, хариулах ямар ч удирдагч, эсвэл ажилчин байхгүй бол чи мөн л дагах замтай байж, дутагдлаа олж мэдэн, өөрийгөө зэвсэглэж, хэрэгжүүлэх учиртай үнэнийг олж чаддаг байх ёстой. Газар дээр ирснийхээ дараа Бурхан хүнийг байнга дагалдаж чадах уу? Өөрсдийн үзлээр зарим хүн: “Бурхан минь, хэрвээ Та биднийг тодорхой хэмжээнд боловсруулахгүй бол Таны ажил дууссан гэж тооцогдохгүй, учир нь Сатан Таныг буруутгана” гэж боддог. Би чамд хэлье, Намайг үгээ хэлж дуусмагц Миний ажил амжилттай дууссан байх болно. Надад нэмж хэлэх юм байхгүй болмогц Миний ажил дуусна. Миний ажлын төгсгөл бол Сатаны ялагдлын нотолгоо бөгөөд тийм болохоор Сатаны ямар ч буруушаалтгүйгээр амжилттай гүйцэлдсэн гэж хэлж болно. Гэхдээ Миний ажил дуусах үед та нарт ямар ч өөрчлөлт байхгүй байвал та нар шиг хүмүүс аврагдахын аргагүй байх ба таягдан хаягдана; Би хэрэгтэй байгаагаас илүү ямар ч ажил хийхгүй. Та нар тодорхой түвшинд байлдан дагуулагдаж, бүгд үнэний тал бүрийг тодорхой мэддэг болж, хэв чанар чинь сайжирч, гаднаа болон дотроо гэрчлэл хийдэг болтол чинь газар дээрх Миний ажил үргэлжлэх юм биш. Тэгэх боломжгүй! Өнөөдөр та нарт хийдэг Миний ажил та нарыг хэвийн хүн чанарын амьдрал руу хөтлөхийн төлөө байдаг; энэ нь шинэ эрин үеийг эхлүүлж, хүн төрөлхтнийг шинэ эрин үеийн амьдрал руу хөтлөх ажил юм. Энэхүү ажил алхам алхмаар та нарын дунд шууд хийгдэж, өрнөдөг: Би та нартай нүүр тулан зааж сургадаг; гараас чинь хөтөлдөг; та нарын ойлгодоггүй юм бүхнийг хэлж, дутагдаж байгаа бүхнийг чинь та нарт хайрладаг. Та нарын хувьд энэ бүх ажил амийн хангалт чинь бөгөөд та нарыг хэвийн хүн чанарын амьдрал руу залж чиглүүлдэг гэж хэлж болно; энэ нь эцсийн өдрүүдэд энэ бүлэг хүмүүсийн амийг тусгайлан хангах зорилготой. Миний хувьд энэ бүх ажил нь хуучин эрин үеийг төгсгөж, шинэ эрин үеийг эхлүүлэх учиртай; Сатаны тухайд гэвэл, яг түүнийг ялахын тулд Би махбод болсон. Одоо та нарын дунд Миний хийдэг ажил бол өнөөдрийн хангалт, цагаа олсон аврал боловч энэ хэдэн богинохон жилд Би та нарт бүх үнэн, амийн бүхий л зам, бүр хожмын ажлыг ч хэлнэ; энэ нь ирээдүйд аливааг хэвийн байдлаар туулах боломжийг та нарт олгоход хангалттай байх болно. Миний бүх үг дангаараа та нарт даалгасан зүйл минь юм. Би өөр ямар ч зүйл захидаггүй; өнөөдөр та нарт Миний хэлдэг бүх үг бол та нарт захих Миний захиас, учир нь өнөөдөр та нар Миний хэлсэн ихэнх үгийг туулаагүй бөгөөд эдгээр үгийн дотоод утга учрыг ойлгодоггүй. Нэг л өдөр та нарын туршлага өнөөдөр Миний ярьж байгаачлан биелэх болно. Эдгээр үг нь та нарын

өнөөдрийн үзэгдэл, хожим тулж түших зүйл, өнөөдрийн амийн хангалт, ирээдүйн захиас бөгөөд өөр илүү дээр захиас гэж байхгүй. Учир нь, газар дээр ажиллах Миний цаг хугацаа, та нар Миний үгийг туулах хугацаа шиг урт биш; Би ердөө ажлаа л гүйцэлдүүлж байгаа, харин та нар амийг эрэлхийлж байгаа ба энэ нь амийн урт удаан аяныг агуулдаг үйл явц юм. Олон зүйлийг туулсныхаа дараа л та нар амийн замыг бүрмөсөн олж авч чадна; тэр үед л та нар өнөөдөр Миний хэлдэг үгийн дотоод утга учрыг нэвт харж чадна. Та нар гартаа Миний үгийг барьж, дор бүрнээ Миний бүх даалгаврыг хүлээн авч, Би та нарт даалгах учиртай бүхнээ даалгаж, хэчнээн их үр нөлөөнд хүрснээс үл хамааран үгийн ажил төгсгөлдөө очих үед Бурханы хүсэл ч бас биелсэн байх болно. Энэ нь чиний төсөөлдөг шигээр чи тодорхой хэмжээнд өөрчлөгдсөн байх ёстой биш; Бурхан чиний үзлийн дагуу үйлддэггүй.

Хүмүүс хэдхэн хоногийн дотор амийн өсөлтөд хүрдэггүй. Бурханы үгийг өдөр бүр идэж, уусан ч гэсэн хангалтгүй. Тэд амийн өсөлтийн хугацааг туулах ёстой. Энэ бол чухал шаардлагатай үйл явц юм. Өнөөдрийн хүмүүсийн хэв чанарыг харгалзан үзвэл, тэд юу хийж чадах вэ? Бурхан хүмүүсийн хэрэгцээний дагуу ажиллаж, төрөлхийн хэв чанарт нь үндэслэн тохиромжтой шаардлага тавьдаг. Энэ ажил илүү хэв чанар сайтай бүлэг хүмүүсийн дунд хийгдсэн гэж үзье: Айлдсан үгс та нарт айлдсанаас илүү өндөр дээд, үзэгдлүүд илүү өндөр сүрлэг, үнэн нь хавьгүй илүү дээр байх байсан. Зарим үг илүү хатуу ширүүн байж, хүмүүсийн амийг хангаж, нууцуудыг илчлэх илүү их чадвартай байх байсан юм. Тийм хүмүүсийн дунд үг хэлэхдээ Бурхан хэрэгцээнийх нь дагуу тэднийг хангах байлаа. Өнөөдөр та нарт тавьсан шаардлагуудыг хамгийн зөв шаардлага гэж хэлж болно; хэрвээ энэ ажлыг хэв чанар сайтай хүмүүсийн дунд хийсэн бол шаардлагууд нь мөн л илүү өндөр байх байлаа. Бурханы бүх ажил нь хүмүүсийн төрөлхийн хэв чанарын дагуу хийгддэг. Өнөөдөр хүмүүсийг өөрчилж, байлдан дагуулсан хэмжээ бол боломжит дээд хэмжээ юм; ажлын энэ үе шат хэр үр нөлөөтэй байсныг хэмжихийн тулд үзлээ бүү ашигла. Та нар төрөлхөөсөө юу эзэмшдэг тухайгаа тодорхой мэдэж байх ёстой бөгөөд өөрсдийгөө хэтэрхий өндрөөр бодох ёсгүй. Анхнаасаа та нараас нэг нь ч амийг эрэлхийлээгүй, харин та нар гудамжинд хэрэн тэнүүчилдэг гуйлгачид байсан. Бурхан та нарыг төсөөлсөн хэмжээнд чинь хүртэл боловсруулж, бүгдийг чинь нүүрээр нь газар унаган мөргүүлж, агуу үзэгдэл харсан мэт бүрэн үнэмшүүлнэ гэвэл тэр нь боломжгүй! Бурханы гайхамшгийг хараагүй хүн Миний хэлдэг үгэнд бүрэн итгэж чаддаггүй учраас энэ нь боломжгүй. Та нар Миний үгийг нарийн шалгасан ч гэсэн тэдгээрт мөн л бүрэн итгэхгүй; энэ нь хүний уг чанар юм! Үнэнийг эрэлхийлдэг хүмүүст зарим нэг өөрчлөлт гарна, харин үнэнийг эрэлхийлдэггүй хүмүүст нэгэнтээ байсан итгэл багасаж, бүр алга болж ч магадгүй. Та нарын хамгийн том бэрхшээл бол Бурханы үгийн биелэлтийг харахгүйгээр бүрэн итгэж чаддаггүй бөгөөд Түүний гайхамшгийг харахгүйгээр хүлээн зөвшөөрдөггүй. Тийм зүйлсийг харалгүйгээр хэн Бурханд туйлын үнэнч байж чадах юм бэ? Иймээс, та

нар Бурханд биш, харин гайхамшигт итгэдэг гэж Би хэлдэг. Би одоо үнэний янз бүрийн талуудын тухай тодорхой ярьсан; тэдгээр нь бүгд бүрэн гүйцэд бөгөөд хоорондоо нягт холбоотой. Та нар тэдгээрийг харсан, одоо хэрэгжүүлэх ёстой. Өнөөдөр Би чамд замыг харуулсан ба ирээдүйд чи үүнийг өөрөө хэрэгжүүлэх ёстой. Одоо Миний хэлдэг үг, бодит орчин нөхцөлд нь үндэслэн хүмүүст шаардлага тавьдаг бөгөөд Би тэдний хэрэгцээ болон тэдний доторх зүйлд нийцүүлэн ажилладаг. Бодитой Бурхан бодитой ажил хийхээр, хүмүүсийн бодит орчин нөхцөл болон хэрэгцээний дагуу ажиллахаар газар дээр ирсэн; Тэрээр бодлогогүй биш. Бурхан үйлдэх үедээ хүмүүсийг албаддаггүй. Жишээлбэл, гэрлэх эсэх чинь чиний хувийн бодит орчин нөхцөлд үндэслэх ёстой; үнэнийг чамд тодорхой хэлсэн бөгөөд Би чамайг хязгаарладаггүй. Зарим хүний гэр бүлийнхэн нь дарамталдаг болохоор гэрлэх хүртлээ Бурханд итгэж чаддаггүй. Иймээс гэрлэлт нь эсрэгээрээ тэдэнд ашигтай байдаг. Бусдынх нь хувьд гэрлэлт ямар ч ашиг тус авчирдаггүй, харин өөрсдөд нь нэгэнтээ байсан зүйлийг үрдэг. Чиний хувьд энэ нь бодит орчин нөхцөл болон хувийн шийдвэрээр чинь тодорхойлогдох ёстой. Би та нарт шаардлага тавих дүрэм журмыг зохиохоор энд байгаа юм биш. “Бурхан бол бодитой; Түүний ажил бодит байдалд болон бидний бодитой орчин нөхцөлд үндэслэдэг” гэж олон хүн байнга хашхирдаг—гэвч үнэндээ юу үүнийг бодит болгодгийг чи мэдэх үү? Хоосон үг бүү хэл! Бурханы ажил бодитой бөгөөд бодит байдалд үндэслэдэг; үүнд хоосон сургаал байдаггүй, харин бүхэлдээ чөлөөтэй, бүгд нээлттэй, илэрхий байдаг. Энэ цөөн хэдэн зарчмын онцгой нарийн ширийн нь юу вэ? Бурханы ажлын аль хэсэг ийм байдгийг чи хэлж чадах уу? Чи нарийвчлан ярих ёстой, туршлагаар олж авсан хэд хэдэн төрлийн гэрчлэл чамд байх ёстой, мөн Бурханы ажлын энэ онцлогийн талаар тун тодорхой мэдэх ёстой—чи үүнийг мэдэх ёстой, тэр үед л эдгээр үгийг хэлэх эрхтэй болно. Хэрвээ хэн нэгэн чамаас: “Бие махбодтой болсон Бурхан эцсийн өдрүүдэд газар дээр ямар ажил хийсэн бэ? Яагаад та нар Түүнийг бодитой Бурхан гэж нэрлэдэг юм бэ? ‘Бодитой’ гэдэг нь юу гэсэн үг вэ? Чи Түүний бодитой ажлын талаар, энэ нь юуг тусгайлан агуулдаг талаар ярьж өгч чадах уу? Есүс махбод болсон Бурхан байсан ба өнөөдрийн Бурхан ч бас махбод болсон Бурхан, тэгвэл Тэдний хоорондох ялгаа юу вэ? Адил төстэй тал нь юу вэ? Тэд дор бүрнээ ямар ажил хийсэн бэ?” гэж асуувал чи хариулж чадах уу? Энэ нь бүгд гэрчлэл хийхтэй хамаатай! Эдгээр зүйлийн талаар бүү будил. Мөн “Өнөөдрийн Бурханы ажил бодит. Тэр хэзээ ч тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй” гэж хэлдэг зарим хүн бий. Тэр үнэхээр тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй юү? Чи итгэлтэй байна уу? Миний ажил үнэндээ юу болохыг чи мэдэх үү? Тэрээр тэмдэг гайхамшиг үзүүлдэггүй гэж хүн хэлж магадгүй, гэхдээ Түүний хийдэг ажил, хэлдэг үг бүгд гайхамшиг биш гэж үү? Тэмдэг гайхамшиг үзүүлдэггүй гэж хэлж магадгүй, гэхдээ энэ нь яаж тайлбарлахаас, мөн хэнд хандан хэлэхээс хамаардаг. Чуулган руу явалгүйгээр Тэр хүмүүсийн байр байдлыг илчилсэн ба үг хэлэхээс өөр ямар ч ажил хийлгүйгээр хүмүүсийг зоригжуулсан—энэ нь гайхамшиг биш гэж үү? Гагцхүү үгээр Тэр хүмүүсийг байлдан

дагуулсан бөгөөд хүмүүс хэтийн ирээдүй юм уу итгэл найдваргүйгээр баяртайяа дагадаг—энэ нь ч бас гайхамшиг биш гэж үү? Түүнийг ярих үед үг нь хүмүүсийн сэтгэл санааны байдалд нөлөөлдөг. Тэдэнд баяр хөөртэй санагдахгүй бол уйтгартай санагддаг; тэд цэвэршүүлэлтэд өртөөгүй бол гэсгээлтэд өртдөг. Тэрээр ердөө цөөн хэдэн хурц үгээр хүмүүст гэсгээлт авчирдаг—энэ нь ер бусын биш гэж үү? Хүмүүс ийм юм хийж чадах уу? Чи энэ олон жил Библи уншсан боловч юу ч ойлгоогүй, ямар ч мэдлэг ухаан олж аваагүй; өөрийгөө тэрхүү хоцрогдсон, уламжлалт итгэлийн арга барилаас ангижруулж чадаагүй. Мөн Библийн учрыг олох аргагүй байдаг. Гэвч Тэр Библийг бүрэн ойлгож чадна—энэ нь ер бусын зүйл биш гэж үү? Хэрвээ Бурханыг газар дээр ирэх үед Түүнд ямар ч ер бусын зүйл байгаагүй бол та нарыг байлдан дагуулж чадах байсан уу? Түүний ер бусын, бурханлаг ажил байгаагүй бол та нарын дундаас хэн үнэмших юм бэ? Чиний нүдэнд хэвийн хүн ажиллаж, та нартай хамт амьдарч байгаа мэт харагддаг—гаднаа Тэр жирийн, хэвийн хүн гэж харагддаг; чи хэвийн хүн чанарын гадаад талыг л хардаг боловч үнэн хэрэгтээ бурханлаг чанар ажиллаж байдаг. Энэ нь хэвийн хүн чанар бус, харин бурханлаг чанар; Бурхан Өөрөө хэвийн хүн чанарыг ашиглан ажиллаж байгаа. Тиймээс Түүний ажил хэвийн байхын сацуу ер бусын байдаг. Түүний хийдэг ажлыг хүн хийж чадахгүй; хэвийн хүмүүс хийж чадахгүй тул ер бусын оршихуй үүнийг хийдэг. Гэвч хүн чанар бус, бурханлаг чанар ер бусын юм; бурханлаг чанар бол хүн чанараас өөр. Ариун Сүнсний ашигладаг хүн ч бас эгэл жирийн, хэвийн хүн чанартай байдаг, гэхдээ тэр энэхүү ажлыг хийх чадваргүй. Энд ялгаа нь оршдог. Чи: “Бурхан бол ер бусын Бурхан биш; Тэр ямар ч ер бусын зүйл хийдэггүй. Бидний Бурхан бодитой агаад жинхэнэ үг хэлдэг. Жинхэнэ, бодитой ажил хийхийн тулд чуулганд ирдэг. Тэрээр өдөр бүр бидэнтэй нүүр тулан ярьж, бидний байр байдлыг зааж хэлдэг—бидний Бурхан үнэхээр бодит! Тэр бидэнтэй хамт амьдардаг, Түүний бүх зүйл тун хэвийн. Харагдах байдлаас нь Бурхан гэж ялгах аргагүй. Түүнд уурлах үе ч байдаг бөгөөд бид уур хилэнгийнх нь сүр жавхланг хардаг, заримдаа Түүнийг инээмсэглэх үед бид инээмсэглэж буй байдлыг нь ажигладаг. Тэр бол хэлбэр галбиртай, мах цусnаас бүтсэн, бодитой агаад жинхэнэ Бурхан Өөрөө мөн” гэж хэлж магад. Чи ийм маягаар гэрчлэл хийвэл энэ нь бүрэн гүйцэд бус гэрчлэл юм. Энэ нь бусдад яаж тус нэмэр болох юм бэ? Хэрвээ чи Бурханы Өөрийн ажлын дотоод түүх болон мөн чанарыг гэрчилж чадахгүй бол чиний “гэрчлэлийг” гэрчлэл гэж нэрлэхэд зохисгүй!

Бурханд гэрчлэл хийх нь үндсэндээ, Бурханы ажил болон Бурхан хүмүүсийг хэрхэн байлдан дагуулдаг, хэрхэн авардаг, хэрхэн өөрчилдөг тухай мэдлэгээ ярих явдал; Тэрээр үнэн-бодит байдалд ороход нь хүмүүсийг хэрхэн замчилж, тэдэнд Түүгээр байлдан дагуулагдаж, төгс болгуулж, аврагдах боломжийг хэрхэн олгодог тухай мэдлэгээ ярих явдал юм. Гэрчлэл хийнэ гэдэг нь Түүний ажлын тухай болон өөрийн туулсан бүхний тухай ярина гэсэн үг юм. Зөвхөн Түүний ажил л Түүнийг төлөөлж чаддаг бөгөөд Түүний ажил л Түүнийг бүхэлд нь ил тод илчилж чадна;

Түүний ажил Түүнд гэрчлэл хийдэг. Түүний ажил болон айлдвар Сүнсийг шууд төлөөлдөг; Түүний хийдэг ажлыг Сүнс хийдэг ба Түүний хэлдэг үгийг Сүнс хэлдэг. Эдгээр зүйл нь ердөө Бурханы махбод болсон биеэр дамжин илэрхийлэгддэг ч үнэндээ тэдгээр нь Сүнсний илэрхийллүүд юм. Түүний хийдэг ажил, хэлдэг үг бүгд Түүний мөн чанарыг төлөөлдөг. Хэрвээ Өөрийгөө махбодоор хувцаслаж, хүмүүсийн дунд ирснийхээ дараа Бурхан үг хэлж, эсвэл ажиллаагүй бөгөөд Өөрийнх нь бодит, хэвийн байдал болон бүхнийг чадагч байдлыг мэдэхийг та нараас шаардсан бол чи чадах байсан уу? Чи Сүнсний мөн чанар юу болохыг мэдэж чадах байсан уу? Түүний махбодын онцлог шинж юу болохыг мэдэж чадах байсан уу? Та нар Түүний ажлын алхам бүрийг туулсан учраас л Тэр та нараас Өөрт нь гэрчлэл хийхийг шаарддаг. Хэрвээ та нарт тийм туршлага байхгүй байсан бол Тэр гэрчлэл хийлгэх гэж зүтгэхгүй байсан билээ. Тиймээс Бурханд гэрчлэл хийх үедээ чи Түүний хэвийн хүн чанарын гадаад байдлыг гэрчлээд зогсохгүй, бас Түүний хийдэг ажил, удирдан чиглүүлдэг замыг гэрчлэх ёстой; мөн Түүгээр хэрхэн байлдан дагуулагдснаа болон ямар талуудад төгс болгуулснаа гэрчлэх ёстой. Энэ нь чиний хийх ёстой гэрчлэл юм. Хэрвээ чи хаашаа ч явсан: “Бидний Бурхан ажиллахаар ирсэн, Түүний ажил үнэхээр бодитой! Тэр ямар ч ер бусын үйлсгүйгээр, ямар ч тэмдэг гайхамшиггүйгээр биднийг олж авсан!” гэж хашхирдаг бол бусад хүмүүс: “Тэр тэмдэг гайхамшиг үзүүлдэггүй гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Тэр тэмдэг гайхамшиг үзүүлэлгүйгээр чамайг байлдан дагуулж яаж чадах юм бэ?” гэж асууна. Тэгэхэд чи: “Тэрээр үг хэлдэг ба ямар ч тэмдэг гайхамшиг үзүүлэлгүйгээр биднийг байлдан дагуулсан. Түүний ажил биднийг байлдан дагуулсан” гэх болно. Эцэст нь, хэрвээ чи бодитой юм хэлж чадахгүй, дэлгэрэнгүй ярьж чадахгүй бол энэ нь жинхэнэ гэрчлэл мөн гэж үү? Бие махбодтой болсон Бурхан хүмүүсийг байлдан дагуулах үед Түүний бурханлаг үг үүнийг хийдэг. Хүн чанар үүнийг гүйцэтгэж чадахгүй; энэ нь зүгээр нэг жирийн хүний хүрч чадах зүйл биш бөгөөд хэвийн хүмүүсийн дундах хэв чанар сайтай хүмүүс ч үүнийг хийж чадахгүй, учир нь Түүний бурханлаг чанар ямар ч бүтээгдсэн зүйлийнхээс илүү өндөр билээ. Хүмүүсийн хувьд энэ нь ер бусын юм; эцсийн эцэст Бүтээгч бол ямар ч бүтээгдсэн зүйлээс илүү өндөр. Бүтээгдсэн зүйлс Бүтээгчээс илүү өндөр байж чадахгүй; хэрвээ чи Түүнээс илүү өндөр байсан бол Тэр чамайг байлдан дагуулж чадахгүй байх байсан бөгөөд Тэр чамаас өндөр учраас л чамайг байлдан дагуулж чадна. Бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж чадах Нэгэн бол Бүтээгч бөгөөд гагцхүү Тэр л энэ ажлыг хийж чадна. Эдгээр үг бол “гэрчлэл”—чиний хийх учиртай гэрчлэл юм. Чи алхам алхмаар гэсгээлт, шүүлт, цэвэршүүлэлт, шалгалт, бүтэлгүйтэл, гай зовлон туулж, байлдан дагуулагдсан; мөн махан биеийн хэтийн ирээдүй, хувийн сэдэл болон махан биеийн хувийн ашиг сонирхлоо хойш тавьсан. Өөрөөр хэлбэл, Бурханы үг чиний зүрх сэтгэлийг бүрэн байлдан дагуулсан. Хэдийгээр чиний амь Түүний шаарддаг шиг их өсөөгүй ч чи энэ бүх зүйлийг мэддэг ба Түүний хийдэг зүйлд бүрэн үнэмшсэн. Тиймээс үүнийг жинхэнэ, бодитой гэрчлэл гэж нэрлэж

болох юм. Бурханы хийхээр ирсэн ажил буюу шүүлт, гэсгээлтийн ажил нь хүнийг байлдан дагуулах зорилготой байдаг боловч Тэр бас Өөрийн ажлыг дуусгаж, эрин үеийг төгсгөж, төгсгөлийн ажлыг гүйцэтгэдэг. Тэр бүхий л эрин үеийг төгсгөж, бүх хүн төрөлхтнийг аварч, хүн төрөлхтнийг нүглээс бүрмөсөн гэтэлгэж байгаа; Тэрээр Өөрийн бүтээсэн хүн төрөлхтнийг бүрэн олж авч байгаа. Чи энэ бүхнийг гэрчлэх ёстой. Чи Бурханы ажлаас маш ихийг туулсан, үүнийг нүдээрээ харж, биечлэн туулсан; бүр эцэст нь хүрэх үедээ чи өөрт оногдсон чиг үүргийг биелүүлэх чадваргүй байж болохгүй. Тэгэх нь хэчнээн харамсалтай байх билээ! Ирээдүйд сайн мэдээ түгэх үед чи хувийн мэдлэгийнхээ талаар ярьж, зүрх сэтгэлдээ олж авсан бүхнээ чадлынхаа хэрээр гэрчилж чаддаг байх ёстой. Энэ бол бүтээгдсэн зүйлийн хүрэх ёстой зүйл юм. Бурханы ажлын энэ үе шатны бодит ач холбогдол юу вэ? Үр нөлөө нь юу вэ? Үүнээс хэр их нь хүнд хийгддэг вэ? Хүмүүс юу хийх ёстой вэ? Та нар бие махбодтой болсон Бурханы газар дээр ирснээсээ хойш хийсэн бүх ажлыг тодорхой ярих үед гэрчлэл чинь бүрэн гүйцэд болно. Чи Түүний ажлын ач холбогдол, агуулга, мөн чанар, төлөөлдөг зан чанар болон зарчмууд гэсэн энэ таван зүйлийн талаар тодорхой ярьж чадвал Бурханд гэрчлэл хийх чадвартай бөгөөд үнэхээр мэдлэгтэй гэдгийг чинь энэ нь батална. Та нарт тавих Миний шаардлага тийм ч өндөр биш бөгөөд үнэхээр эрж хайдаг бүх хүн хүрэх боломжтой. Хэрвээ чи Бурханыг гэрчлэгчдийн нэг байхаар шийдвэл Бурхан юуг үзэн ядаж, юуг хайрладгийг ойлгох ёстой. Чи Түүний ажлын ихээхнийг туулсан; энэ ажлаар дамжуулан Түүний зан чанарыг мэдэж авч, Түүний хүсэл болон хүн төрөлхтөнд тавих Түүний шаардлагыг ойлгоод, энэ мэдлэгээ ашиглан Түүнийг гэрчилж, үүргээ биелүүлэх ёстой. Чи: “Бид Бурханыг мэднэ. Түүний шүүлт, гэсгээлт маш хатуу. Түүний үг маш ширүүн; тэдгээр нь зөвт агаад сүр жавхлантай, мөн ямар ч хүн халдашгүй” гэж хэлж л магадгүй ч эцсийн эцэст эдгээр үг хүнийг хангадаг уу? Хүмүүст үзүүлэх үр нөлөө нь юу вэ? Шүүлт, гэсгээлтийн энэ ажил чамд хамгийн их ашиг тустай гэдгийг чи үнэхээр мэдэх үү? Бурханы шүүлт, гэсгээлт нь чиний тэрслүү зан болон завхралыг илчилж байгаа биз дээ? Тэдгээр нь чиний доторх бузар, завхарсан зүйлсийг цэвэрлэж, үлдэн хөөж чадна биз дээ? Шүүлт, гэсгээлт байгаагүй бол чи яах байсан бэ? Сатан чамайг хамгийн гүн гүнзгий завхруулсан гэдгийг чи үнэхээр ухамсарладаг уу? Өнөөдөр та нар эдгээр зүйлээр өөрсдийгөө зэвсэглэж, тэдгээрийг сайн мэддэг байх ёстой.

Өнөө үед Бурханд итгэх итгэл нь та нарын төсөөлдөг итгэл шиг—Бурханы үгийг уншиж, залбирч, дуулж, бүжиглэж, үүргээ биелүүлж, хэвийн хүн чанарын амьдралаар амьдрах нь хангалттай байдаг юм биш. Итгэл бишрэл ийм энгийн байж болох уу? Үр дүн гол нь юм. Аливааг хэр олон арга замаар хийдэг чинь биш, харин яг яаж хамгийн сайн үр дүнд хүрч чадах нь чухал. Чи Бурханы үгийг барьж, зарим мэдлэгээ тайлбарлаж чадаж магадгүй боловч үүнийг доош тавих үедээ хэлэх юмгүй байдаг. Чи зөвхөн бичиг үсэг, хоосон сургаал л ярих чадвартай боловч чамд туршлагын мэдлэг байдаггүйг энэ нь харуулдаг. Өнөөдөр чи гол чухал зүйлийг

ухаарч чадахгүй бол нэмэргүй—энэ нь бодит байдалд ороход амин чухал юм! Өөрийгөө ийнхүү дадлагажуулж эхэл: Эхлээд Бурханы үгийг унш; тэдгээрийн доторх сүнслэг нэр томьёог сайн мэдэж ав; тэдгээрийн дотроос гол үзэгдлүүдийг ол; хэрэгжүүлэлттэй холбоотой хэсгүүдийг тодорхойл; энэ бүх элементийг нэг нэгээр нь нэгтгэ; туршлагаараа тэдгээрт ор. Эдгээр нь чиний ухаарах ёстой гол зүйл юм. Бурханы үгийг идэж, уухад хамгийн чухал хэрэгжүүлэлт бол энэ: Бурханы үгийн нэг бүлгийг уншсаныхаа дараа чи үзэгдэлтэй холбоотой гол хэсгүүдийг олж тодорхойлж чаддаг байх ёстой, хэрэгжүүлэлттэй холбоотой гол хэсгүүдийг ч бас олж тодорхойлж чаддаг байх ёстой; үзэгдлүүдийг суурь болгож, хэрэгжүүлэлтийг амьдралынхаа хөтөч болгон ашигла. Энэ бол та нарт хамгийн их дутагддаг зүйл, та нарын хамгийн том бэрхшээл юм; зүрх сэтгэлдээ та нар үүнд анхаарал хандуулах нь ховорхон. Ерөнхийдөө, та нар бүгд залхуу, урам зориггүй, хувийн золиос гаргах дургүй байдалтай байдаг; эсвэл идэвхгүйгээр хүлээж, зарим нь бүр гомдоллодог; тэд Бурханы ажлын зорилго, ач холбогдлыг ойлгодоггүй ба тэдний хувьд үнэнийг эрэлхийлэхэд хэцүү байдаг. Тийм хүмүүс үнэнийг жигшдэг ба эцэстээ таягдан хаягдана. Тэдний дундаас нэг нь ч төгс болгуулж чадахгүй, нэг нь ч амьд үлдэхгүй. Хэрвээ хүмүүст Сатаны нөлөөг эсэргүүцэх багахан шийдвэр байхгүй бол тэд ямар ч найдлагагүй!

Одоо, та нарын эрэл хайгуул үр нөлөөтэй байсан эсэхийг одоогоор юу эзэмшиж байгаад чинь үндэслэн хэмждэг. Та нарын төгсгөлийг тодорхойлоход үүнийг ашигладаг; өөрөөр хэлбэл, гаргасан золиослол, хийсэн зүйлсээр чинь та нарын төгсгөл илчлэгддэг. Та нарын эрэл хайгуул, итгэл болон хийсэн зүйл төгсгөлийг чинь харуулна. Та нарын дунд аль хэдийн аврагдах аргагүй болсон хүмүүс олон бий, учир нь өнөөдөр бол хүмүүсийн төгсгөлийг илчлэх цаг үе бөгөөд Би ажлаа будилуу байдлаар хийхгүй; аврагдаж ер чадахгүй хүмүүсийг дараагийн эрин үе рүү хөтлөхгүй. Миний ажил дуусах цаг ирнэ. Би огтхон ч аврагдаж чадахгүй тэр өмхий, сүнсгүй цогцоснууд дээр ажиллахгүй; одоо үе бол хүнийг аврах эцсийн өдрүүд бөгөөд Би хэрэггүй ажил хийхгүй. Тэнгэр, газрыг бүү загна—дэлхий ертөнцийн төгсгөл ирж байна. Энэ бол зайлшгүй. Юмс иймдээ тулсан ба хүн болохын хувьд чи тэдгээрийг зогсоох юу ч хийж чадахгүй; чи аливааг хүссэнээрээ өөрчилж чадахгүй. Өчигдөр чи үнэнийг эрэлхийлэхдээ төлөөс төлөөгүй бөгөөд үнэнч бус байсан; өнөөдөр цаг нь ирсэн, чи аврагдахын аргагүй; маргааш чи таягдан хаягдах бөгөөд чиний хувьд аврагдах ямар ч боломжгүй. Хэдийгээр Миний зүрх сэтгэл эелдэг зөөлөн бөгөөд чамайг аврахын тулд Би чадах бүхнээ хийж байгаа ч хэрвээ чи өөрийнхөө өмнөөс чармайж, өөрийгөө огт бодохгүй бол энэ нь Надад ямар хамаатай юм бэ? Өөрсдийн махан биеийг л боддог, тав тухтай байдалд дуртай хүмүүс; итгэдэг юм шиг мөртөө үнэндээ итгэдэггүй хүмүүс; хар дом болон хар шидэнд оролцдог хүмүүс; садар самуун, навсгар, ноорхой хүмүүс; Еховагийн тахилыг болон эд хөрөнгийг хулгайлдаг хүмүүс; хээл хахуульд дуртай хүмүүс; тэнгэр өөд гарах тухай хий дэмий мөрөөддөг хүмүүс; хувийн алдар нэр, эд

хөрөнгийн төлөө л тэмцдэг биеэ тоосон, ихэрхүү хүмүүс; эрээ цээргүй үг тараадаг хүмүүс; Бурханыг Өөрийг нь доромжилдог хүмүүс; Бурханыг Өөрийг нь шүүж, гүжирдэхээс өөрийг хийдэггүй хүмүүс; бүлэглэл үүсгэж, бие даасан байдлаа эрэлхийлдэг хүмүүс; өөрсдийгөө Бурханаас дээр өргөмжилдөг хүмүүс; садар самуун байдалд урхидуулсан хөнгөмсөг залуучууд, дунд эргэм болон ахмад насны эрчүүд, эмэгтэйчүүд; хувийн алдар нэр, эд хөрөнгийг таашааж, бусад хүмүүсийн дунд хувийн байр суурь хөөцөлддөг эрчүүд, эмэгтэйчүүд; нүгэлд урхидуулсан, гэмшдэггүй тэр хүмүүс—тэд бүгд аврагдах аргагүй бус уу? Садар самуун, нүгэлтэй байдал, хар дом, хар шид, хараал зүхэл, эрээ цээргүй үгс бүгд та нарын дунд хяналтгүй тархдаг; үнэн болон амийн үгс та нарын дунд дэвслүүлж, ариун хэл та нарын дунд бузарлагддаг. Харь үндэстнүүд та нар бузар заваан болон дуулгаваргүй байдлаар дүүрэн! Та нарын эцсийн төгсгөл хаана байх вэ? Махан биеийг хайрладаг, махан биеийн хар шид үйлддэг, садар самуун нүгэлд урхидуулдаг хүмүүс үргэлжлүүлэн амьдрах ичгүүр сонжуургүй байж яаж чадах юм билээ! Та нар шиг хүмүүс бол аврагдахын аргагүй өт хорхой гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Яаж энэ, тэрийг шаардах эрхтэй байх юм бэ? Өнөөг хүртэл, үнэнийг хайрладаггүй, зөвхөн махан биеийг л хайрладаг хүмүүст өчүүхэн төдий ч өөрчлөлт гараагүй—ийм хүмүүс яаж аврагдаж чадах юм бэ? Амийн замыг хайрладаггүй, Бурханыг өргөмжилж, Түүнд гэрчлэл хийдэггүй, байр суурийнхаа төлөө хуйвалддаг, өөрсдийгөө магтдаг хүмүүс—өнөөдөр ч гэсэн, хэвээрээ байгаа бус уу? Тэднийг аврахын үнэ цэн юу вэ? Аврагдаж чадах эсэх чинь хэр ахмад вэ гэдгээс чинь, эсвэл хэдэн жил ажиллаж байгаагаас чинь хамаардаггүй, тэр ч бүү хэл хэр их мэргэшсэнээс чинь хамаардаггүй. Харин ч, чиний эрэл хайгуул үр дүнд хүрсэн эсэхээс хамаардаг. Аврагддаг хүмүүс бол өтгөн саглагар навчтай, арвин их цэцэгтэй боловч жимсэлдэггүй мод биш, харин жимсэлдэг “мод” юм гэдгийг чи мэдэх учиртай. Чи олон жилийг гудамжинд тэнэж өнгөрүүлсэн байлаа ч тэр ямар хамаатай юм бэ? Чиний гэрчлэл хаана байна? Бурханыг гэх чиний хүндлэл өөрийгөө хайрлах хайр болон тачаангуй хүслээс чинь хавьгүй бага—ийм хүн доройтмол биш гэж үү? Тэд яаж авралын үлгэр дуурайл, загвар байж чадах юм бэ? Чиний уг чанар өөрчлөгдөшгүй, чи хэтэрхий тэрслүү, аврагдах аргагүй! Ийм хүмүүс таягдан хаягдах хүмүүс бус уу? Миний ажил дуусах үе нь чиний сүүлчийн өдөр ирэх үе биш гэж үү? Би та нарын дунд маш их ажил хийж, маш олон үг хэлсэн—үүнээс хэр их нь чихэнд чинь орсон бэ? Хэр ихийг нь та нар дуулгавартай дагасан бэ? Миний ажил дуусах үе нь чи Намайг эсэргүүцэхээ больж, Миний эсрэг зогсохоо болих үе юм. Намайг ажиллаж байхад та нар байнга Миний эсрэг үйлддэг; та нар Миний үгийг хэзээ ч мөрддөггүй. Би Өөрийн ажлыг хийдэг ба чи хувийн “ажлаа” хийж, жижигхэн хаанчлалаа байгуулдаг. Та нар бол сүрэг үнэг, нохой төдий бөгөөд Намайг эсэргүүцэн бүхнийг хийдэг! Та нар өөрсдийг чинь хоёргүй сэтгэлээр хайрладаг хүмүүсийг л тэврэн авахаар байнга хичээж байгаа—хүндлэл чинь хаана байна вэ? Та нарын хийдэг бүхэн ов мэхтэй! Та нарт ямар ч дуулгавартай байдал,

эсвэл хүндлэл байхгүй бөгөөд ов мэхтэй, гүтгэн доромжилсон бүхнийг л хийдэг! Тийм хүмүүс аврагдаж чадах уу? Бэлгийн ёс суртахуунгүй, садар самуун эрчүүд өөрсдийн зугаа цэнгэлийн төлөө, сээтэгнэсэн янхнуудыг өөрсдөдөө татахыг үргэлж хүсэж байдаг. Би бэлгийн ёс суртахуунгүй тийм чөтгөрүүдийг яавч аврахгүй. Би бузар чөтгөрүүд та нарыг үзэн яддаг ба хуял тачаал, сээтэгнүүр зан чинь та нарыг там руу унагасан. Та нар өөрсдийгөө өмөөрч юу хэлэх юм бэ? Бузар чөтгөрүүд болон муу ёрын сүнснүүд та нар үзэшгүй муухай! Жигшүүртэй! Ийм хог новшнууд яаж аврагдаж чадах юм бэ? Нүгэлд урхидуулсан хүмүүс мөн л аврагдаж чадна гэж үү? Өнөөдөр, энэ үнэн, энэ зам болон энэ амь та нарын сэтгэлийг татдаггүй; харин ч та нар нүгэлт байдал, мөнгө, зэрэг зиндаа, алдар нэр, ашиг хонжоо, махан биеийн зугаа цэнгэл, эрчүүдийн царайлаг байдал, эмэгтэйчүүдийн ялдам занд сэтгэл татагддаг. Та нар яаж Миний хаанчлалд орох эрхтэй байх юм бэ? Та нарын дүр Бурханыхаас ч илүү агуу, та нарын байр суурь Бурханыхаас ч өндөр бөгөөд хүмүүсийн дундах нэр хүндийг чинь ярихын ч хэрэггүй—та нар хүмүүсийн шүтдэг шүтээн болжээ. Чи тэргүүн тэнгэрэлч болоогүй гэж үү? Хүмүүсийн төгсгөл илчлэгдэх үед тэр нь бас авралын ажил дуусах дөхсөн үе байх бөгөөд та нарын дундаас олонх чинь аврагдахын аргагүй, таягдан хаягдах ёстой цогцоснууд болно. Авралын ажлын үеэр Би бүх хүнд эелдэг зөөлөн, сайн ханддаг. Ажил дуусах үед өөр өөр төрлийн хүмүүсийн төгсгөл илчлэгдэх бөгөөд тэр үед Би эелдэг зөөлөн, сайн байхаа болино, учир нь хүмүүсийн төгсгөл илчлэгдэж, бүгд төрлийнхөө дагуу ангилагдсан байх болно. Мөн авралын эрин үе өнгөрөн одсон байх ба нэгэнт өнгөрсөн зүйл эргэн ирэхгүй учраас авралын ажлыг цаашид хийх ямар ч хэрэггүй байна.

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ 8

Та нар үнэний янз бүрийн талыг мөн л ойлгодоггүй бөгөөд хэрэгжүүлэлтэд чинь нэлээд хэдэн алдаа, гажуудал байсаар байдаг; та нар олон талбарт үзэл, төсөөллөөрөө амьдарч, хэрэгжүүлэлтийн зарчмыг хэзээ ч ухаарч чаддаггүй. Тиймээс зөв замд ороход нь хүмүүст мөн л замчлах шаардлагатай байдаг; өөрөөр хэлбэл, ингэснээр тэд хүмүүний амьдрал болон сүнслэг амьдралаа зохицуулж, аль аль талыг нь хэрэгжүүлж чадах ба байнга дэмжүүлж, замчлуулах хэрэггүй болно. Зөвхөн тэр үед л тэд жинхэнэ биеийн хэмжээтэй болно. Ирээдүйд чамайг залж чиглүүлэх хэн ч байхгүй байсан ч гэсэн чи мөн л өөрөө туршлагажиж чадна. Өнөөдөр чи үнэний аль тал нь чухал, аль нь чухал биш болохыг ухаарвал ирээдүйд бодит байдалд орж чадна. Өнөөдөр та нар зөв зам руу хөтлүүлж, олон үнэнийг ойлгох боломжтой болсон ба хожим нь илүү гүн явж чадна. Одоо хүмүүст ойлгуулж байгаа зүйл бол хамгийн цэвэр зам юм гэж хэлж болно. Өнөөдөр чамайг зөв зам руу аваачиж байгаа—нэг л өдөр чамайг залж чиглүүлэх хэн ч байхгүй байх үед чи бүх замаас хамгийн цэвэр энэ замын дагуу хэрэгжүүлж, илүү гүн урагшилна.

Өнөөдөр хүмүүст ямар хэрэгжүүлэлт зөв, ямар нь гажууд болохыг ойлгуулж байгаа. Эдгээр зүйлийг ойлгосны дараа ирээдүйд тэдний туршлага улам гүнзгийрнэ. Өнөөдөр үзэл, төсөөлөл, хэрэгжүүлэлт дэх гажуудлыг чинь урвуулж, хэрэгжүүлэлт болон оролтын замыг та нарт илчилж байгаа, үүний дараа ажлын энэ үе шат төгсөж, та нар хүмүүсийн явах учиртай замаар алхаж эхэлнэ. Тэгээд Миний ажил дуусна, тэр мөчөөс эхлээд та нар Надтай дахин уулзахгүй. Өнөөдөр та нарын биеийн хэмжээ жижиг хэвээр байна. Хүний уг чанар-мөн чанараас урган гардаг олон хүндрэл бэрхшээл байдаг тул хараахан ухаж гаргаагүй гүн үндэслэсэн зүйлс ч бас байдаг. Та нар хүмүүсийн уг чанар-мөн чанарын илүү нарийн ширийнийг ойлгодоггүй бөгөөд Надаар заалгах хэрэгтэй хэвээр байдаг, эс бөгөөс та нар тэдгээрийг танин мэдэж чадахгүй. Тодорхой мөчид та нарын яс, цусан доторх зүйлс ил болох үед үүнийг гэсгээлт, шүүлт гэж нэрлэдэг. Миний ажил нэгд нэггүй, бүрэн гүйцэд явагдсан үед л Би үүнийг дуусгана. Завхарсан мөн чанар чинь хэдий чинээ гүн гүнзгий илчлэгдэнэ, та нар төдий чинээ их мэдлэг эзэмших бөгөөд энэ нь ирээдүйн гэрчлэл болон төгс төгөлдөржилтөд чинь асар их ач холбогдолтой байх болно. Гэсгээлт, шүүлтийн ажил нэгд нэггүй явагдсан үед л Миний ажил гүйцэлдэж, та нар Намайг гэсгээлт, шүүлтээс минь мэдэж авна. Та нар Миний зан чанар, зөвт байдлыг мэдээд зогсохгүй, үүнээс ч чухал нь Миний гэсгээлт, шүүлтийг мэдэх болно. Та нарын дундах олон хүн, Миний ажлын шинэлэг байдал болон нарийн ширийний түвшний талаар асар их үзэлтэй байдаг. Ямартай ч, Миний ажил бол шинэ, дэлгэрэнгүй гэдгийг болон Би та нартай нүүр тулан, гараас чинь бариад, хэрэгжүүлэх талаар заадаг гэдгийг та нар харах учиртай. Зөвхөн энэ л та нарын хэрэгжүүлэлт болон ирээдүйд бат зогсох чадварт чинь ашиг тустай; эс бөгөөс та нар өчүүхэн ч үнэ цэнгүй, гандаж, шарлаж, хатсан намрын навчис шиг байх болно. Би зүрх сэтгэл болон сүнсэн дэх бүх зүйлийг чинь мэддэг гэдгийг та нар мэдэх ёстой; Миний хийдэг ажил, хэлдэг үгс ч бас асар нарийн гэдгийг мэдэх ёстой. Та нарын зан чанар болон хэв чанарт үндэслэвэл та нартай ингэж харьцах учиртай. Ийм маягаар л Миний гэсгээлт, шүүлтийн талаарх та нарын мэдлэг илүү тодорхой болж, чи өнөөдөр мэдэхгүй байсан ч гэсэн маргааш мэднэ. Ямар ч бүтээгдсэн зүйл Миний гэсгээлт, шүүлтийн үгэн дунд унана, учир нь Би Намайг эсэргүүцэхийг хэнд ч зөвшөөрдөггүй.

Та нар бүгд өөрсдийнхөө амьдралыг ухаалгаар зохицуулж чаддаг байх ёстой. Өдөр бүрийг хүссэнээрээ зохицуулж болно; хүссэн болгоноо хийж болно; Бурханы үгийг уншиж, магтан дуу юм уу номлол сонсож, эсвэл сүнслэг үйл ажиллагааны тэмдэглэл хөтөлж болно; хэрвээ сонирхлыг чинь татвал магтан дуу зохиож ч болно. Энэ бүхэн зөв зүйтэй амьдралыг бүрдүүлдэггүй гэж үү? Эдгээр нь хүний амьдралыг бүрдүүлэх учиртай бүх зүйл юм. Хүмүүс жам ёсоороо амьдрах ёстой; хэвийн хүн чанар болон сүнслэг амьдралынхаа аль алинд үр ашиг хүртсэн үед л тэднийг хэвийн амьдралд орлоо гэж тооцож болно. Өнөөдөр, зөвхөн хүн чанарын тухайд чамд мэдлэг ухаан, эрүүл ухаан дутуу дулимаг байдаг юм биш. Хүмүүсийн

зэвсэглэх ёстой, мэдэх учиртай олон үзэгдэл ч бас байдаг бөгөөд чи ямар ч хичээлтэй тулгарсан бай, тэр нь чиний сурах ёстой хичээл юм; чи орчин нөхцөлд дасан зохицож чаддаг байх ёстой. Боловсролын түвшнээ үр ашигтай байлгахын тулд чи удаан хугацааны туршид сайжруулах ёстой. Хэвийн, хүний амьдралтай байхын тулд өөрийгөө зэвсэглэх ёстой зарим зүйл байдаг ба чи бас амийн оролтоо ойлгох ёстой. Өнөөдөр, тухайн үед ойлгоогүй зүйлээ дахин уншаад чи Бурханы олон үгийг ойлгож авсан бөгөөд зүрх сэтгэл чинь улам тууштай болсон. Эдгээр нь ч бас чиний хүрсэн үр дүн юм. Бурханы үгийг идэж уусан, мөн дотор чинь бага зэргийн мэдлэг байгаа аль ч өдөр чи ах эгч нартайгаа чөлөөтэй ярилцаж болно. Энэ нь чамд байх учиртай амьдрал бус уу? Заримдаа зарим нэг асуулт тавьж, эсвэл нэг сэдвийг тунгаан боддог ба энэ нь чамайг ялган танихдаа илүү сайн болгож, чамд илүү гүн ойлголт, мэргэн ухааныг өгч, зарим үнэнийг ойлгох боломж олгодог—энэ нь өнөөдрийн ярьсан сүнслэг амьдрал дотор агуулагддаг зүйл биш гэж үү? Сүнслэг амьдралын зөвхөн нэг талыг хэрэгжүүлэх нь хүлээн зөвшөөрөгдөхгүй; Бурханы үгийг идэж, уух, залбирах, магтан дуу дуулах нь бүгд сүнслэг амьдралыг бүрдүүлдэг ба сүнслэг амьдралтай байх үедээ чи бас хэвийн хүн чанарын амьдралтай байх ёстой. Өнөөдөр, хэлж буй зүйлсийн ихэнх нь хүмүүст эрүүл ухаан, мэдлэг өгч, тэднийг хэвийн хүн чанарын амьдралтай болгохын төлөө байдаг. Мэдлэгтэй байна гэж юу гэсэн үг болох; хүн хоорондын хэвийн харилцаатай байна гэж юу гэсэн үг болох; хүмүүстэй хэрхэн харилцах ёстой—чи Бурханы үгийг идэж, ууснаар дамжуулан эдгээр зүйлээр зэвсэглэх ёстой бөгөөд чамаас шаарддаг зүйлд хэвийн хүн чанараар хүрэх боломжтой. Зэвсэглэх ёстой зүйлээрээ өөрийгөө зэвсэглэ, зүй зохистой хэмжээнээс бүү хэтрүүл; зарим хүн төрөл бүрийн үг, үгсийн сан ашигладаг ба үүгээрээ тэд сайрхан онгирдог. Мөн төрөл бүрийн ном уншиж, улмаар махан биеийн хүслийг өөгшүүлдэг хүмүүс байдаг. Тэд бүр дэлхийн агуу хүмүүс хэмээгдэгсэдийн намтар болон хэлсэн үгийг судалж, дуурайдаг бөгөөд садар самуун ном уншдаг—энэ нь бүр ч инээдтэй! Ийм хүмүүс амийн оролтын замыг мэддэггүй, тэр ч бүү хэл өнөөдрийн Бурханы ажлыг мэддэггүй. Тэд өдөр бүрийг хэрхэн өнгөрүүлэхээ ч мэддэггүй. Амьдрал нь тийм хоосон байдаг! Тэд юунд орох ёстой тухайгаа огт мэддэггүй. Тэгээд бусадтай ярьж, харилцахаас өөрийг хийдэггүй ба ярих нь тэдний оролтыг орлодог мэт байдаг. Тэд ичгүүргүй бус уу? Эдгээр нь хэрхэн амьдрахаа мэддэггүй, хүний амьдралыг ойлгодоггүй хүмүүс юм; тэд ховдоглон идэж, утгагүй зүйл хийж бүхий л өдрийг өнгөрүүлдэг—ийм маягаар амьдрах ямар хэрэгтэй юм бэ? Олон хүний хувьд ажиллаж, идэж, хувцаслахаас гадна хөгжилдөн наадах, тоглоом шоглоом хийх, хов жив ярих, өдөржин унтах гэх мэтээр өөрсдийнхөө үнэт цагийг утга учиргүй зүйлд зарцуулж байдгийг Би харсан. Энэ нь ариун хүний амьдрал мөн үү? Энэ нь хэвийн хүний амьдрал мөн үү? Амьдрал чинь дорд, хоцрогдмол, хайхрамжгүй байх үед ийм амьдрал чамайг төгс болгож чадах уу? Чи өөрийгөө Сатанд дэмий алдахад бэлэн байна уу? Хүмүүсийн амьдрал амар хялбар байж, эргэн тойронд нь ямар ч зовлон байхгүй байх үед тэд

туршлагажих чадваргүй байдаг. Тав тухтай орчинд хүмүүс доройтохдоо амархан байдаг—гэхдээ хүнд хэцүү орчин нь чамайг асар их яаравчлан залбирахад хүргэх ба чамайг Бурханыг орхин явж зүрхлэхгүй байхад хүргэдэг. Амьдрал нь амар хялбар, үлбэгэр байх тусмаа, хүмүүст амьдрах утгагүй гэж улам их санагддаг бөгөөд үхсэн нь дээр гэж ч санагддаг. Хүмүүсийн махан бие ийм завхарсан; шалгалт туулах үедээ л тэд ашиг тус хүртэж чадна.

Есүсийн ажлын үе шат нь Иудейд болон Галилд хийгдсэн бөгөөд Харь үндэстнүүд энэ талаар мэдээгүй. Түүний хийсэн ажил тун нууц байсан ба Израилиас өөр ямар ч улс үндэстэн энэ талаар мэдээгүй юм. Есүс ажлаа гүйцэлдүүлж, энэ нь үймээн шуугиан дэгдээх үед л хүмүүс мэдсэн бөгөөд тэр үед Есүс явж одсон байв. Есүс ажлын нэг үе шатыг хийхээр ирээд, зарим хүнийг олж авч, ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлсэн. Бурханы хийдэг ажлын аль ч үе шатанд Түүнийг дагадаг олон хүн байдаг. Хэрвээ үүнийг Бурхан Өөрөө л хийдэг бол энэ нь утга учиргүй байх байлаа; ажлын тэр үе шатыг эцэст нь хүртэл хийтэл Бурханыг дагах хүмүүс байх ёстой. Бурханы Өөрийн ажил дуусах үед л хүмүүс Бурханы даалгасан ажлыг хэрэгжүүлж эхэлдэг ба тэр үед л Бурханы ажил түгж эхэлдэг. Бурхан шинэ эринийг эхлүүлэх ажлыг л хийдэг; хүмүүсийн ажил үүнийг үргэлжлүүлдэг. Тиймээс өнөөдрийн ажил удаан үргэлжлэхгүй; хүнтэй хамт байх Миний амьдрал тийм ч удаан үргэлжлэхгүй. Би Өөрийн ажлыг л гүйцэлдүүлэх ба гүйцэтгэх учиртай үүргийг чинь та нараар гүйцэтгүүлнэ, ингэснээр энэхүү ажил, энэхүү сайн мэдээ нь Харь үндэстнүүд болон бусад улс үндэстэнд аль болох хурдан түгж чадна—ингэж л та нар хүмүүсийн хувиар үүргээ биелүүлж чадна. Өнөөдрийн цаг үе бол хамгийн эрхэм нандин билээ. Үүнийг үл ойшоовол чи мунхаг юм; энэхүү орчинд эдгээр үгийг идэж, ууж, энэ ажлыг туулдаг атлаа үнэнийг эрэлхийлэх шийдвэр дутмаг хэвээр, ачаа үүрэх өчүүхэн төдий ч мэдрэмжгүй байвал ирээдүй чинь ямар байх вэ? Чам шиг хүмүүс таягдан хаягдахад бэлэн болсон бус уу?

ИЗРАИЛЬЧУУД ШИГ ҮЙЛЧИЛ

Өнөө үед олон хүн, бусадтай хамтран ажиллах зууraa ямар хичээл сурах ёстой талаар анхаарал хандуулдаггүй. Бусадтай хамтран ажиллах зууraa та нарын олонх нь хичээл сурч чаддаггүй гэдгийг Би олж илрүүлсэн; та нарын дийлэнх нь үзэл бодолтойгоо зууралддаг. Чуулганд ажиллах үедээ чи өөрийнхөө бодлыг, өөр нэг нь ч бас өөрийнхийгөө хэлдэг ба нэг нь нөгөөтэйгөө ямар ч холбоогүй байдаг; та нар үнэндээ огтхон ч хамтран ажилладаггүй. Та бүхэн амийг өчүүхэн төдий ч эрж хайлгүйгээр, өөрсдийн ойлголтыг ярилцах юм уу дотроо тээдэг “ачааг” чөлөөлөх гэж л их шимтдэг. Чи ажлыг гагцхүү хааш яаш хийж, бусад хүн юу ч хэлж, хийсэн хамаагүй, өөрийнхөө замаар алхах ёстой гэж үргэлж итгэдэг юм шиг харагддаг;

мөн бусдын орчин нөхцөл ямар байх нь хамаагүй, Ариун Сүнс чамайг залж чиглүүлэхийн хэрээр нөхөрлөх ёстой гэж чи боддог. Та нар бусдын давуу талыг олж илрүүлж чаддаггүй, өөрсдийгөө шинжилж ч чаддаггүй. Аливааг хүлээн зөвшөөрч байгаа чинь үнэхээр гажууд бөгөөд алдаа мадагтай. Одоо ч гэсэн та нар нөгөө хууч өвчин нь сэдэрсэн мэт өөрсдийгөө ихэд зөвтгөсөөр байдаг гэхэд болно. Та нар бүрэн илэн далангүй байдалд хүрэх замаар жишээлбэл, зарим чуулганы ажлаар ямар үр дүнд хүрсэн тухай, дотоод байдлынхаа саяхны нөхцөлийн талаар гэх мэтийг өөр хоорондоо ярилцдаггүй; та нар тийм зүйлсийг ер нь хэзээ ч ярилцдаггүй. Үзлээ орхих, өөрсдийгөө хаях зэргийг яавч хэрэгжүүлдэггүй. Удирдагчид болон ажилчид, ах эгч нараа хэрхэн сөрөг болгохгүй байж, яаж тэднийг идэвхтэй дагаж чаддаг болгох талаар л боддог. Харин идэвхтэй дагах нь дангаараа хангалттай гэж та нар бүгд боддог бөгөөд өөрийгөө мэдэж, өөрийгөө хаях гэдэг нь ямар утгатайг үндсэндээ ойлгодоггүй, бусадтай хамтран үйлчилнэ гэж юу гэсэн үг болохыг бүр ч ойлгодоггүй. Өөрсдөө Бурханы хайрыг хариулж, Петрийн хэв маягийг амьдран харуулах хүсэлтэй байх тухай л боддог. Эдгээр зүйлээс өөр юуг ч боддоггүй. Бусад хүн юу хийх нь хамаагүй, би сохроор захирагдахгүй, бусад хүн ямар байх нь хамаагүй, Бурханаар төгс болгуулах гэж би өөрөө л эрж хайна, тэгэх нь хангалттай гэж хүртэл хэлдэг. Гэвч үнэн хэрэгтээ чиний хүсэл бодит байдал дээр биелэлээ огтхон ч олоогүй. Энэ бүхэн нь өнөө үед та нарын гаргадаг зан авир биш гэж үү? Та нар дор бүрнээ өөрсдийн мэдлэг ухаантай зууралдаж, бүгд төгс болгуулахыг хүсдэг. Та нар ийм урт хугацаанд төдийлөн их ахиц гаргалгүй үйлчилсэн гэдгийг Би хардаг; ялангуяа хамтдаа эв эетэй ажиллах энэ хичээл дээр та нар бүр юунд ч хүрээгүй! Чуулганд очихдоо чи өөрийнхөө арга барилаар ярилцдаг, бусад нь өөрсдийнхөөрөө ярилцдаг. Эв эетэй зохицол хаяа бий болдог бөгөөд ялангуяа та нарын доор буй дагагчдын хувьд энэ нь бүр ч үнэн байдаг. Өөрөөр хэлбэл, та нарын дундаас тун цөөхөн нь Бурханд үйлчлэх гэж юу болохыг, эсвэл хүн Бурханд хэрхэн үйлчлэх ёстойг ойлгодог. Та нар будилж төөрөлдөн, иймэрхүү хичээлийг ялихгүй асуудал гэж үздэг. Үнэний энэ талыг хэрэгжүүлж чаддаггүй олон хүн байдгаар үл барам, бас зориуд буруу юм хийдэг хүмүүс ч бий. Олон жилийн турш үйлчилсэн хүмүүс хүртэл өөр хоорондоо тэмцэлдэж, бие биеийнхээ эсрэг хуйвалддаг, мөн атаархаж, өрсөлддөг; хүн бүр хувиа боддог ба огтхон ч хамтран ажилладаггүй. Энэ бүх зүйл бодит биеийн хэмжээг чинь төлөөлдөг бус уу? Хүмүүс та нарын өдөр тутам хамтдаа үйлчилж байгаа чинь Бурханд Өөрт нь сүм дотор өдөр бүр шууд үйлчилдэг байсан израильчуудтай адилхан. Бурханд үйлчилдэг хүмүүс та нар хэрхэн хамтран ажиллаж, хэрхэн үйлчлэхээ мэдэхгүй байж яаж болох юм бэ?

Тухайн үед израильчууд сүмд Еховад шууд үйлчилж байсан бөгөөд тахилчийн ялгамж чанартай байлаа. (Мэдээж, хүн бүр тахилч байгаагүй; сүм дотор Еховад үйлчилж байсан зарим хүн л тийм ялгамж чанартай байсан юм.) Тэд өөрсдөд нь Еховагийн хайрласан титмийг (тэд энэ титмийг Еховагийн шаардлагад нийцүүлэн

хийсэн болохоос Ехова тэдэнд шууд титэм өгөөгүй гэсэн үг) өмсдөг байв. Тэд бас Еховагийн өгсөн тахилчийн хувцсыг өмсөн, хөл нүцгэнээр өглөөнөөс үдэш болтол сүм дотор Түүнд шууд үйлчилдэг байлаа. Еховад үйлчлэх тэдний үйлчлэл огтхон ч замбараагүй байгаагүй бөгөөд сохроор яаран гүйдэг ч байгаагүй; харин энэ бүхэн нь Еховад шууд үйлчилж байсан хэний ч зөрчиж болохгүй дүрэм журмын дагуу хийгддэг байжээ. Тэд бүгд энэ дүрэм журмыг мөрдөх ёстой байв; эс бөгөөс сүмд орохыг нь хориглох байлаа. Хэрвээ тэдний хэн нэг нь сүмийн дүрмийг зөрчвөл—өөрөөр хэлбэл, хэн нэг нь Еховагийн тушаалд үл захирагдвал—тэр хүнд Еховагийн гаргасан хуулийн дагуу хандах ёстой бөгөөд хэн ч үүнийг эсэргүүцэж, эсвэл гэм буруутныг хамгаалж болдоггүй байв. Тэд хэчнээн олон жил Бурханд үйлчилсэн нь хамаагүй, бүгд уг дүрэм журмыг мөрдөх шаардлагатай байсан юм. Ийм учраас, маш олон тахилч тахилчийн өмсгөл өмсөөд, Ехова өөрсдөд нь онцгойлон хандаагүй хэдий ч ийм маягаар жилийн турш Еховад тасралтгүй үйлчилдэг байжээ. Тэр ч бүү хэл, тэд бүхий л амьдралаа тахилын ширээний өмнө, сүм дотор өнгөрөөдөг байв. Тэдний үнэнч, дуулгавартай байдлын илрэл энэ байлаа. Ехова тэдэнд тийм ерөөл хайрласанд гайхах юмгүй; үнэнч зангийнхаа үрээр тэд ивээл хүртэж, Еховагийн бүх үйл хэргийг харсан юм. Тухайн үед, Израильд Өөрийн сонгосон хүмүүсийн дунд ажиллаж байх үедээ Ехова тэдэнд нэлээд хатуу чанд шаардлага тавьжээ. Тэд бүгд маш дуулгавартай байж, хуулиар хязгаарлагдаж байв; эдгээр хууль Еховаг хүндлэх чадварыг нь хамгаалахад ашиглагдсан юм. Энэ бүхэн нь Еховагийн захиргааны зарлиг байлаа. Хэрвээ тэдгээр тахилчийн аль нэг нь Амралтын өдрийг сахиагүй юм уу Еховагийн тушаалыг зөрчсөн бол, мөн энгийн иргэдэд мэдэгдсэн бол тэр хүнийг нэн даруй тахилын ширээний өмнө аваачиж, чулуугаар шидэж хөнөөдөг байв. Тийм цогцсуудыг сүмийн дотор юм уу, ойр хавьд нь тавихыг зөвшөөрдөггүй байжээ; Ехова тэгэхийг зөвшөөрөөгүй юм. Ийнхүү үйлдсэн хэнийг ч “бузар тахил” өргөсөн хүн гэж үзээд том нүхэнд хаяж, цаазалдаг байв. Мэдээж, тийм бүх хүн амиа алддаг, нэгийг нь ч өршөөдөггүй байлаа. Тэр ч байтугай, “бузар гал” өргөсөн хүмүүс ч байсан юм; өөрөөр хэлбэл, Еховагийн тогтоосон өдрүүдэд тахил өргөөгүй хүмүүсийн тахилын зүйлсийг тахилын ширээн дээр үлдээхийг зөвшөөрдөггүй, хүнтэй нь хамт Еховагийн галд шатаадаг байжээ. Тахилчдад дараах шаардлагыг тавьдаг байлаа: Эхлээд хөлөө угаалгүйгээр сүмд юм уу бүр сүмийн гадна хашаанд ч орохыг зөвшөөрдөггүй; тэд тахилчийн өмсгөлөө өмсөөгүй бол сүмд орж болдоггүй; тахилчийн титмээ өмсөөгүй бол сүмд орж болдоггүй; цогцосноос бохирдсон бол сүмд орж болдоггүй; зөв шударга бус хүний гарт хүрснийхээ дараа эхлээд гараа угаагаагүй бол сүмд орж болдоггүй; эмэгтэй хүнээс бузартсаныхаа дараа сүмд орж болдоггүй (үүрд биш, харин гурван сарын турш), Еховагийн царайг харахыг бас зөвшөөрдөггүй байлаа. Цаг нь болоход буюу гурван сарын дараа л тахилчийн цэвэрхэн өмсгөл өмсөхийг тэдэнд зөвшөөрнө—тэгээд гадна хашаанд долоо хоног үйлчилснийхээ дараа сүмд орж, Еховагийн царайг харж чаддаг байв. Еховагийн сүмийг бузарлахаас сэргийлэхийн тулд

тахилчийн аль ч хувцсыг гадаа өмсөхийг хэзээ ч зөвшөөрдөггүй, зөвхөн сүм дотор өмсөхийг зөвшөөрдөг байжээ. Тахилч байсан бүх хүн Еховагийн хуулийг зөрчсөн гэмт хэрэгтнүүдийг Түүний тахилын ширээний өмнө аваачих ёстой бөгөөд тэнд энгийн иргэдээр цаазлуулах ёстой байв; эс бөгөөс гэмт хэргийг харсан тахилч дээр гал буудаг байлаа. Тийнхүү Еховагийн хууль маш хатуу чанд байсан учраас тэд Еховад туйлын үнэнч байж, Түүний захиргааны зарлигийг хээв нэг зөрчиж хэрхэвч зүрхэлдэггүй байлаа. Израильчууд Еховагийн галын дөлийг харж, хүмүүсийг гэсгээдэг гарыг нь харсан учраас, мөн анхнаасаа Еховаг гэх тийм их хүндлэл өвөрлөж байсан учраас Түүнд үнэнч байсан юм. Тиймээс тэд зөвхөн Еховагийн галын дөлийг төдийгүй Түүний халамж, хамгаалалт, ерөөлийг хүртсэн билээ. Бүх үйлдэлдээ Еховагийн үгийг мөрдөж, хэн ч дуулгаваргүй байгаагүй нь тэдний үнэнч зан байв. Ямар нэгэн дуулгаваргүй байдал гарах юм бол бусад нь Еховагийн үгийг хэрэгжүүлж, Еховаг эсэргүүцсэн хэнийг ч цаазалдаг байсан бөгөөд тэр хүнийг Түүнээс огт нуудаггүй байлаа. Амралтын өдрийг зөрчсөн хүмүүс, завхайрсан хүмүүс, Еховагийн тахилыг хулгайлсан хүмүүсийг гойд хатуу шийтгэдэг байв. Амралтын өдрийг зөрчсөн хүмүүсийг ч ялгаагүй тэд (энгийн иргэд) чулуугаар цохиж алах юм уу, эсвэл үхтэл нь ташуурддаг байв. Садар самуун үйлдэгсдийг—сэтгэл татам эмэгтэйчүүдийн араас шунан тачааддаг юм уу, нүгэлт эмэгтэйчүүдийг хараад завхай зайдан бодол сэддэг, эсвэл залуу бүсгүйчүүдийг хараад тачааддаг хүмүүсийг—бүгдийг нь цаазалдаг байлаа. Нөмрөг юм уу, гивлүүр зүүгээгүй ямар ч залуу бүсгүй эрэгтэй хүнийг зүй бус харилцаанд уруу татвал тэр эмэгтэйг ч бас цаазалдаг байсан. Хэрвээ иймэрхүү хууль зөрчсөн хүн нь тахилч (сүмд үйлчилдэг хүн) бол цовдлох юм уу дүүжилдэг байжээ. Тийм нэг ч хүнд амьдрахыг зөвшөөрдөггүй, ганц нь ч Еховагийн өмнө таалал хүртдэггүй байлаа. Ийм хүний хамаатан саданд түүнийг үхсэнээс хойш гурван жилийн хугацаанд тахилын ширээний өмнө Еховад тахил өргөхийг зөвшөөрдөггүй, энгийн иргэдэд Еховагийн олгосон тахилаас хуваалцахыг ч зөвшөөрдөггүй байв. Тэр хугацаа дуусахад л тэд Еховагийн тахилын ширээн дээр шилмэл үхэр юм уу, хонь тавьж болдог байлаа. Хэрвээ өөр ямар нэгэн гэм буруу үйлдсэн бол тэд Еховагийн өмнө гурав хоног мацаг барьж, Түүний нигүүлслийг гуйх ёстой байв. Еховагийн хууль маш хатуу, чанд байсан учраас л тэд Еховаг шүтэн мөргөсөн юм биш; Түүний нигүүлсэл, Түүнд үнэнч байдгаасаа үүдэн шүтэн мөргөсөн юм. Тийм болохоор тэд өнөөг хүртэл үйлчлэлдээ нэгэн адил үнэнч хэвээр үлдсэн бөгөөд Еховагийн өмнөх гуйлтаасаа хэзээ ч буцаж няцаагүй. Өнөө үед Израилийн ард түмэн Еховагийн халамж, хамгаалалтыг хүлээн авсаар байгаа бөгөөд Тэрээр тэдний дундах нигүүлсэл хэвээр байж, тэдэнтэй хамт үргэлж оршин байдаг. Тэд Еховаг хэрхэн хүндлэх ёстойгоо, Түүнд хэрхэн үйлчлэх ёстойгоо бүгд мэддэг бөгөөд Түүний халамж, хамгаалалтыг хүлээн авахын тулд хэрхэн үйлдэх ёстойгоо бүгд мэддэг; учир нь тэд бүгдээрээ зүрх сэтгэлдээ Түүнийг хүндэлдэг. Тэдний үйлчлэлийн амжилтын нууц нь хүндлэлээс өөр юу ч биш. Тэгвэл өнөө үед та бүхэн ямархуу байдаг вэ?

Израилийн ард түмэнтэй адил төстэй зүйл та нарт байдаг уу? Өнөө үеийн үйлчлэл нь агуу сүнслэг хүний удирдлагыг дагахтай адил гэж чи боддог уу? Та нарт үнэнч зан, хүндлэл ердөө байдаггүй. Та нар ихээхэн нигүүлсэл хүртдэг ба бүгд Бурханд шууд үйлчилдгээрээ Израилийн тахилчидтай эн тэнцүү. Хэдий та нар сүмд ордоггүй ч хүлээн авдаг болон хардаг зүйл чинь сүмд Еховад үйлчилж байсан тахилчдын хүлээн авсан зүйлээс хавьгүй их. Гэсэн ч та нар тэднээс илүү олон удаа тэрсэлж, эсэргүүцдэг. Та нарын хүндлэл тун өчүүхэн, үүнээсээ үүдэн тун бага нигүүлсэл хүртдэг. Хэдийгээр та нар тун багыг зориулдаг ч израильчуудын хүртсэнээс хавьгүй ихийг хүлээн авсан. Энэ бүхэнд та нарт өгөөмөр хандаж байгаа хэрэг биш үү? Израильд ажил хийгдэж байх зуур хүмүүс Еховаг зоргоороо шүүж зүрхлээгүй. Гэтэл та нар яадаг вэ? Одоо хийж байгаа ажил минь та нарыг байлдан дагуулахын төлөө байгаагүй бол Миний нэрийг маш ичгүүр сонжуургүйгээр шившиглэж байгааг чинь Би яахан тэвчиж чадах билээ? Та нарын амьдардаг эрин үе Хуулийн эрин үе байсан бол үг яриа, үйлдлээс чинь үзвэл та нараас нэг нь ч амьд үлдэхгүй байх байсан. Та нарын хүндлэл тун өчүүхэн! Өөрсдөд нь их ивээл хайрласангүй гэж та нар Намайг үргэлж буруутгаж байгаа ба та нарт ерөөлийн хангалттай үг өгдөггүй, та нарыг зөвхөн хараадаг гэж ч хэлдэг. Намайг тийм бага хүндэлдэг болохоор Миний ерөөлийг хүлээн авах боломжгүй гэдгээ та нар мэдэхгүй гэж үү? Үйлчлэл чинь өрөвдөлтэй байдгаас болж Би та нарыг байнга харааж, шүүж байдгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нарыг хэлмэгдүүлсэн мэт санагддаг уу? Тэрслүү агаад захирагддаггүй бүлэг хүмүүст Би яаж ерөөлөө хайрлаж чадах юм бэ? Миний нэрд гутамшиг авчирдаг хүмүүст Би нигүүлслээ хааш яаш хайрлаж яаж чадах юм бэ? Та нарт аль хэдийн туйлын сайхан хандсан. Израильчууд өнөөдрийн та нар шиг тэрслүү байсан бол Би тэднийг аль эрт устгачих байсан юм. Гэхдээ Би та нарт гагцхүү хүлээцтэй ханддаг. Энэ нинжин сэтгэл биш үү? Та нар үүнээс ч их ерөөлийг хүсэж байна уу? Өөрийг нь хүндэлдэг хүмүүсийг л Ехова ерөөдөг. Өөрийнх нь эсрэг тэрсэлдэг хүмүүсийг Тэр гэсгээж, нэгийг нь ч ер уучилдаггүй. Хэрхэн үйлчлэхээ мэддэггүй өнөөдрийн та нарын зүрх сэтгэлийг бүрэн эргүүлэхийн тулд гэсгээлт, шүүлт бүр ч их хэрэгтэй биш гэж үү? Ийм гэсгээлт, шүүлт нь та нарт хүртээж буй хамгийн сайн ерөөл биш гэж үү? Энэ нь та нарын хамгийн сайн хамгаалалт биш гэж үү? Үүнгүйгээр та нар Еховагийн дүрэлзсэн галыг тэсэж чадна гэж үү? Хэрвээ та нар үнэхээр израильчууд шиг үнэнч үйлчилж чадвал та нарыг ч бас нигүүлсэл байнга дагалдах бус уу? Бас та нарт баяр хөөр, хангалттай ивээл үргэлж байх бус уу? Та бүхэн хэрхэн үйлчлэх ёстойгоо мэдэх үү?

Өнөөдөр та нарт хамтдаа эв эетэй ажиллах шаардлага тавьсан нь Еховагийн израильчуудаас шаардаж байсан үйлчлэлтэй төстэй: Эс бөгөөс зүгээр л үйлчлэл хийхээ боль. Та нар Бурханд шууд үйлчилдэг хүмүүс учраас хамгийн наад зах нь үйлчлэлдээ үнэнч, дуулгавартай байх чадвартай, мөн бодитой байдлаар сургамж авч чаддаг байх ёстой. Ялангуяа чуулганд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд доор чинь буй ах, эгч нарын хэн нэг нь та нартай харьцаж зүрхлэх үү? Та нарын алдааг

нүүрэн дээр чинь хэлж зүрхлэх үү? Та нар өрөөл бусдаас өндөрт зогсдог; хаад мэт хаанчилдаг! Тэр ч бүү хэл, та нар иймэрхүү бодитой хичээлийг судалдаггүй, үүнд ордоггүй мөртөө Бурханд үйлчлэх тухай ярьсаар байдаг! Одоогоор хэд хэдэн чуулганыг удирдахыг чамаас хүссэн боловч чи өөрийгөө орхиогүйгээр үл барам, бүр өөрийн үзэл, санаа бодолтой зууралдан “Бид бусдад хязгаарлагдах ёсгүй, өнөө үед сохроор захирагдах ёсгүй гэж Бурхан хэлсэн тул энийг ийм маягаар хийх ёстой гэж би бодож байна” гэх мэт зүйл хэлдэг. Тиймээс та нар дор бүрнээ өөрсдийнхөө санал бодлыг баримтлаад, хэн нь ч хэнийгээ дуулгавартай дагадаггүй. Үйлчлэл чинь мухардалд орсон гэдгийг тодорхой мэдэж байгаа ч “Миний харж байгаагаар, миний арга зам тийм ч хол зөрөөгүй байна. Ямар ч байсан, бидний аль алинд нэг тал бий: Чи өөрийнхийгөө ярь, би өөрийнхийгөө ярья; чи өөрийнхөө үзэгдлийг нөхөрлө, би өөрийнхөө оролтыг ярья” гэж хэлсээр байдаг. Та нар шийдвэрлэх ёстой олон зүйл дээр хэзээ ч хариуцлага хүлээдэггүй, эсвэл зүгээр л аргалдаг ба дор бүрнээ өөрсдийн санал бодлыг илэрхийлж, байр суурь, алдар хүнд, нэр нүүрээ болгоомжтой хамгаалдаг. Та нарын аль нь ч өөрийгөө даруухан байлгахыг хүсдэггүй бөгөөд амиа илүү хурдан өсгөхийн тулд аль ч тал нь өөрийгөө орхиж, нэг нэгнийхээ дутагдлыг нөхөх санаачилга гаргахгүй. Та нар хамтран ажиллаж байхдаа үнэнийг эрэлхийлж сурах ёстой. “Би үнэний энэ талыг тодорхой ойлгодоггүй. Чамд үүнтэй холбоотой ямар туршлага байдаг вэ?” гэж чи хэлж болно. Эсвэл, “Энэ талаар чи надаас илүү туршлагатай; надад бага зэрэг удирдамж өгч болох уу?” гэж болох юм. Тэгэх нь үүнийг хийх сайн арга зам биш гэж үү? Та нар ихээхэн номлол сонссон ба үйлчлэл хийх бага зэрэг туршлагатай. Чуулганд ажил хийж байхдаа бие биеэсээ суралцдаггүй, нэг нэгэндээ тусалдаггүй, бие биеийнхээ дутагдлыг нөхдөггүй бол та нар яаж ямар нэг хичээл сурч чадах юм бэ? Та нар ямар нэг зүйлтэй тулгарах болгондоо нэг нэгтэйгээ нөхөрлөх ёстой, ингэвэл амь чинь ашиг тус хүртэж чадна. Түүнчлэн, ямар нэг шийдвэр гаргахаасаа өмнө аливаа зүйлийн талаар хянуур нөхөрлөх ёстой. Ингэснээр л та нар хааш яаш авирлахын оронд чуулганы төлөө хариуцлага хүлээнэ. Бүх чуулганаар зочилсныхоо дараа та нар цуглаж, олж илрүүлсэн бүх асуудал болон ажилд чинь тулгарсан аливаа асуудлын талаар нөхөрлөх ёстой, дараа нь хүлээн авсан гэгээрэл, гэрэлтүүлэлтийнхээ талаар ярилцах ёстой—энэ бол үйлчлэлийн зайлшгүй чухал хэрэгжүүлэлт юм. Та нар Бурханы ажлын зорилгын төлөө, чуулганы ашиг тусын төлөө, мөн ах эгч нартаа түлхэц өгөхийн тулд эв эетэй хамтын ажиллагаанд хүрэх ёстой. Бурханы хүслийг анхаарахын тулд чи бусадтайгаа хамтран ажиллаж, бие биеэ засаж залруулан ажлын илүү дээр үр дүнд хүрэх ёстой. Жинхэнэ хамтын ажиллагаа гэж энэ бөгөөд үүнд оролцдог хүмүүс л жинхэнэ оролтыг олж авна. Хамтран ажиллах зуураа хэлэх зарим үг чинь тохиромжгүй байж болох ч тэр хамаагүй. Энэ талаар дараа нь нөхөрлөж, илүү тодорхой ойлголттой бол; үүнийг бүү үл ойшоо. Иймэрхүү нөхөрлөлийн дараа ах, эгч нарынхаа дутагдлыг нөхөж чадна. Ийм маягаар ажилдаа улам гүн орсноор л илүү сайн үр дүнд хүрч чадна. Бурханд үйлчилдгийн

хувьд та нар дор бүрнээ өөрсдийнхөө ашиг сонирхлыг л харгалзан үзэхийн оронд хийдэг юм болгондоо чуулганы ашиг сонирхлыг хамгаалж чаддаг байх ёстой. Ганцаараа үйлдэн, нэг нэгнээ муутгах нь хүлээн зөвшөөрөхийн аргагүй юм. Тэгж авирладаг хүмүүс Бурханд үйлчлэхэд тохирохгүй! Тийм хүмүүс муухай зан чанартай байдаг; тэдэнд өчүүхэн төдий ч хүн чанар үлдээгүй байдаг. Тэд бол зуун хувь Сатан мөн! Тэд бол арааТнууд! Одоо ч гэсэн, тийм зүйлс та нарын дунд тохиолддог хэвээр; та нар бүр нөхөрлөлийн үеэр нэг нэг рүүгээ дайрч давшилж, албаар шалтаг хайж, ялихгүй жаахан асуудал дээр нүүрээ минчийтэл маргалдаж, хэн нь ч найр тавихыг хүсдэггүй, хүн бүр дотроо бодсоноо нөгөөгөөсөө нууж, нөгөө талаа анхааралтай ажиглаж, үргэлж сэрэмжлэхдээ тулдаг. Иймэрхүү зан чанар Бурханд үйлчлэхэд тохирох уу? Та нарынх шиг тийм ажил ах, эгч нарыг ямар нэгэн зүйлээр хангаж чадах уу? Чи хүмүүсийг амийн зөв зам руу залж чиглүүлж чаддаггүйгээр үл барам, үнэндээ завхарсан зан чанараа ах, эгч нартаа шингээж байдаг. Чи бусдыг хорлож байгаа бус уу? Чиний мөс чанар аймшигтай бөгөөд голдоо ортол илжирсэн байна! Чи бодит байдалд ордоггүй, үнэнийг ч хэрэгжүүлдэггүй. Түүнчлэн, диавол шиг уг чанараа ичгүүр сонжуургүйгээр бусдад илчилдэг. Чи ерөөсөө ичихээ мэддэггүй! Энэ ах, эгч нарыг чамд даалгасан атал чи тэднийг там руу аваачиж байна. Чи мөс чанар нь илжирсэн хүн биш гэж үү? Чамд ичих нүүр огт алга!

ХЭВ ЧАНАРЫГ ӨСГӨХ НЬ БУРХАНЫ АВРАЛЫГ ХҮЛЭЭН АВАХЫН ТӨЛӨӨ ЮМ

Хүмүүсийн хэв чанарыг өсгөнө гэдэг нь, Бурханы үгийг ойлгож, хэрхэн хэрэгжүүлэхээ мэддэг болохын тулд ойлгох чадвараа сайжруулахыг та нараас шаардана гэсэн үг юм. Энэ бол хамгийн үндсэн шаардлага. Юу хэлж байгааг минь ойлгохгүйгээр Намайг дагадаг бол итгэл чинь будилуу бус уу? Би хэчнээн их үг айлдлаа гээд хэрэв та нар ойлгож хүчрэхгүй, Намайг юу ч хэлсэн бай нэг л сайн ойлгохгүй байвал та нар дорд хэв чанартай байна гэсэн үг юм. Ойлгох чадваргүйгээр та нар Миний хэлдэг зүйлээс юу ч ойлгохгүй тул хүссэн үр дүнд хүрэхэд маш хэцүү болдог; Би та нарт шууд хэлж чаддаггүй маш их зүйл байдаг бөгөөд зорьсон үр дүнд хүрч чаддаггүй тул нэмэлт ажил шаардагддаг. Та нарын ойлгох чадвар, аливааг харах чадвар болон амьдардаг стандарт хэтэрхий дутагдалтай болохоор “хэв чанарыг өсгөх” ажлыг та нар дээр хэрэгжүүлэх ёстой. Энэ нь зайлшгүй бөгөөд өөр сонголт үгүй билээ. Тэгснээр л зарим нэг үр дүнд хүрч чадна; эс бөгөөс, Миний хэлдэг бүх үг ямар ч хэрэггүй болно. Тэгвэл та нар түүхэнд нүгэлтэн болж үлдэх биш үү? Хамгийн өөдгүй хүмүүс болохгүй гэж үү? Та нар дээр ямар ажил гүйцэтгэж байгааг, та нараас юу шаардаж байгааг мэдэхгүй гэж үү? Та нар хэв чанараа мэдэх учиртай: Хэв чанар чинь Миний шаардлагад огт нийцдэггүй.

Тиймээс энэ нь Миний ажлыг хойш татахгүй гэж үү? Одоогийн хэв чанар, ёс жудагт чинь үндэслэвэл та нарын хэн нь ч Надад гэрчлэл хийхэд тохирохгүй, мөн хэн нь ч ирээдүйн ажлын минь хүнд хариуцлагыг үүрэх чадваргүй. Та нар ихэд ичихгүй байна уу? Ийм маягаар үргэлжлүүлбэл та нар Миний хүслийг хангалуун байлгаж яаж чадах билээ? Чи амьдралдаа чадах чинээгээрээ амьдрах ёстой. Цаг хугацааг дэмий бүү өнгөрүүл—тэгэх нь ямар ч үнэ цэнгүй. Өөрийгөө юугаар зэвсэглэх учиртайгаа чи мэдэх ёстой. Өөрийгөө арван хуруу тэгш гэж бүү бод—туулах зам чинь мөн л урт байна! Хүн чанарын жаахан ч атугай эрүүл ухаан чамд байхгүй бол өөр юу ч хэлэх билээ? Бүх зүйл дэмий болох биш үү? Миний шаарддаг хүн чанар, хэв чанарын тухайд бол, та нараас хэн чинь ч шаардлагад бүрэн нийцдэггүй. Ашиглахад тохирох нэгнийг олох туйлын хэцүү байдаг. Та нар өөрсдийгөө Миний төлөө илүү агуу ажил хийж, Надаас илүү агуу даалгавар авч чадна гэж итгэдэг ч үнэндээ өмнө чинь илхэн байгаа олон хичээл рүү хэрхэн орохоо ч мэддэггүй юм чинь илүү гүнзгий үнэн рүү хэрхэн орж чадах билээ? Та нарын оролт үелсэн хандлага, түвшинтэй байх ёстой. Эмх замбараагүй байх ёсгүй—тэгвэл нэмэргүй. Хамгийн өнгөцхөн оролтоос эхэл: Ойлголт, тодорхой байдалд хүртлээ эдгээр үгийг мөр мөрөөр нь унш. Бурханы үгийг унших үедээ мориор давхингаа цэцэгсийг бахдан харах адил бүү гүйлгэн унш, бас уншсан нэр ч бүү зүү. Чи мэдлэгээ нэмэгдүүлэхийн тулд лавлах номуудыг (дүрмийн, эсвэл яруу илтгэх зүйн номууд гэх мэт) ч бас тогтмол уншиж болно. Романтик роман, агуу хүмүүсийн намтар, нийгмийн шинжлэх ухааны тухай ном бүү унш; эдгээр нь ямар ч ашиг тусгүй бөгөөд хор хөнөөл учруулж л чадна. Чи орох, ойлгох ёстой бүхнээ эзэмших ёстой. Хүмүүсийн хэв чанарыг өсгөх нь тэдэнд мөн чанар, ялгамж чанар, байр суурь, үнэ цэнийх нь талаар мэдлэг өгөх зорилготой юм. Хүмүүс яагаад Бурханд итгэх итгэлийн үнэнийг эрэлхийлэх ёстойг чи ойлгох хэрэгтэй. Сурч боловсорсоор байх шаардлагатай; үүнийг хаяж болохгүй! Яагаад хүмүүсийн хэв чанарыг өсгөх ёстой, яаж өсгөх ёстой, мөн ямар талууд руу орох хэрэгтэйг та нар ойлгох ёстой. Хэвийн хүн чанарыг амьдран харуулахын ач холбогдол, энэ ажлыг яагаад хийх ёстойг болон хүний гүйцэтгэх учиртай үүргийг ч ойлгох ёстой. Жишээлбэл, боловсролтой болохдоо та нар, аль талуудыг судлах хэрэгтэйг, хүн тэдгээрт яаж орох вэ гэдгийг ойлгох ёстой. Сурч боловсрохын зорилгыг та нар бүгд мэдэж байх хэрэгтэй. Энэ нь Бурханы үгийг ойлгож, үнэн рүү орохын төлөө биш гэж үү? Чуулганууд даяар өнөөдөр юу давамгайлдаг вэ? Хүмүүсийг боловсролтой болгуулах нь Бурханы үгийг эдлэхээ мартахад тэднийг хүргэдэг бөгөөд тэд бүхэл өдөржингөө сурч боловсрохоос өөр юу ч хийдэггүй. Чи тэднээс хэвийн хүн чанарыг амьдран харуулахыг шаардвал тэд гэр орноо цэвэрлэж, хоол хийж, эсвэл гал тогооны хэрэгсэл худалдан авахад л санаа тавина. Эдгээр зүйлд л тэдний гол анхаарал төвлөрнө; тэд бүр чуулганы хэвийн амьдралаар хэрхэн амьдрахыг ч мэдэхгүй байх болно. Хэрвээ чи ийм нөхцөл байдалд байгаа бол хэрэгжүүлэлтээсээ хазайгаад явчихжээ. Тэгвэл яагаад чамаас сүнслэг амьдрал руу орохыг шаарддаг юм бэ?

Ердөө л тэдгээр зүйлийг сурах нь чамайг шаардлага биелүүлэх чадваргүй болгож орхино. Амь руу орох нь мөн л хамгийн чухал зүйл юм; харин тэр ажлыг хийж буйн шалтгаан нь туршлагынх нь явцад хүмүүст тулгардаг бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд байдаг. Хэв чанарыг чинь өсгөх нь чамд хүний уг чанар, мөн чанарын тухай мэдлэг өгдөг бөгөөд үүний гол зорилго нь хүмүүсийн сүнслэг амийг өсгөж, зан чанарыг нь өөрчлөх явдал юм. Чи яаж хувцаслаж, өөрийгөө яаж сайхан харагдуулахаа мэддэг байж болно, мөн ажигч гярхай, ухаалаг байж ч болно, гэхдээ эцсийн эцэст ажилдаа явах өдөр ирэхэд чи явж чадахгүй. Тиймээс хэв чанараа өсгөх явцад өөр бас юу хийх ёстойгоо чи мэдэж байх ёстой. Зорилго нь чамайг өөрчлөх явдал; хэв чанарыг чинь өсгөх нь нэмэлт юм. Хэв чанар чинь сайжрахгүй бол нэмэргүй, зан чанар чинь өөрчлөгдөхгүй бол бүр ч долоон дор. Алийг нь ч орхигдуулж болохгүй. Хэвийн хүн чанарыг эзэмших нь цангинасан гэрчлэл хийчихсэн гэсэн үг биш—чамаас шаарддаг зүйл тийм ч энгийн биш.

Хүмүүсийн хэв чанар нь, хэвийн хүн чанартай хүмүүсийн эрүүл ухаан, амьдралын хэв маягт хүрэх хэмжээнд өргөгдөж, бас амь руу орсон үед л тэд ярих өөрчлөлт, гэрчлэлтэй болно. Гэрчлэл хийх өдөр ирэхэд амьдралдаа гарсан өөрчлөлт болон өөрийн доторх Бурханы тухай мэдлэгээ ч бас ярих ёстой. Энэ хоёр талын хослол л чиний жинхэнэ гэрчлэл болон чиний ургац юм. Хүн чанар чинь гаднаа өөрчлөгдсөн боловч дотроо ямар ч ойлголтгүй байвал хангалтгүй, мөн дотроо үнэн болон ойлголттой байгаа ч хэвийн хүн чанарыг амьдран харуулахаа огоорч гүйцвэл бас л нэмэргүй. Өнөөдөр чам дээр хийгддэг ажил бусдад харуулахын тулд биш, харин чамайг өөрчлөхийн төлөө байдаг. Чи өөрийгөө өөрчлөхөд л анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Өдөр бүр бичиж, сонсохоос өөрийг хийхгүй амьдарвал нэмэргүй; тал бүрд оролттой байх ёстой. Чи ариун хүний хэвийн амьдралаар амьдрах ёстой. Олон эгч залуу бүсгүйчүүд шиг, ах нар сурвалжтан юм уу нөлөө бүхий хүмүүс шиг хувцаслаж, ариун хүний ямар ч төрхгүй байдаг. Хүний хэв чанарыг өсгөх гэдэг зүйл нь явцын дунд биелдэг. Бурханы үгийг идэж, уух өөр нэг зүйл бол гол түлхүүр юм. Хэв чанар чинь өссөн ч Бурханы үгийг идэж, уугаагүйгээс болоод хэрэглэгдэхгүй бол сурах хүчин чармайлт чинь талаар болох биш үү? Хоёр талыг хослуулах ёстой. Чамаас шаарддаг зүйлийн талаар хэлэлцэж байхад яагаад Бурханы тухай мэдлэгийг сөхдөг юм бэ? Энэ нь ажлын үр дүнг гаргахын төлөө байдаг бус уу? Байлдан дагуулагдсаныхаа дараа чи өөрийнхөө туршлагаар гэрчлэл хийж чаддаг байх ёстой. Гаднаа хэвийн хүн чанартай харагддаг хэр нь туршлагаа үгээр илэрхийлж чаддаггүй байж таарвал нэмэргүй. Хэвийн сүнслэг амьдралтай байх зуураа чи бас хэвийн хүн чанарт хүрэх ёстой бөгөөд үүний олон талыг санаандгүй сурч авна. Шал шүүрдэхэд хүртэл тодорхой дадлага хэрэгтэй гэж чи бодож байна уу? Үүнээс ч долоон дор зүйл бол хоол идэхдээ савхаа барьж сурахын тулд нэг цагийг зарцуулах явдал юм! Хэвийн хүн чанарт ямар талууд агуулагддаг вэ? Гүн ойлголт, эрүүл ухаан, мөс чанар болон ёс жудаг. Эдгээр тал бүрд хэвийн байдалд хүрч чадвал хүн чанар чинь зүйд нийцнэ.

Чи хэвийн хүний төрхтэй, Бурханд итгэгчтэй төстэй байх ёстой. Хэтэрхий ихийг биелүүлж, эсвэл дипломат ёсонд оролцох хэрэггүй; чи зүгээр л хэвийн хүний эрүүл ухаантай хэвийн хүн байж, аливааг нэвт харж чаддаг, ядахдаа хэвийн хүн шиг харагддаг байх ёстой. Тэр нь л хангалттай. Өнөөдөр чамаас шаарддаг бүхэнд чадвар чинь хүрнэ; огт боломжгүй зүйл шаардаж байгаа хэрэг биш. Нэг ч хэрэгцээгүй үг, эсвэл хэрэгцээгүй ажлыг чам дээр гүйцэтгэхгүй. Амьдралд чинь илэрхийлэгдэж, илчлэгдсэн бүх муу муухай байдлаасаа чи ангижрах ёстой. Та нарыг Сатан завхруулсан бөгөөд Сатаны хороор бялхаж байдаг. Энэхүү завхарсан сатанлаг зан чанараасаа ангижрахыг л чамаас шаарддаг. Өндөр албан тушаалтай, эсвэл алдартай, агуу хүн бол гэж чамаас шаарддаггүй. Тэглээ гээд ямар ч хэрэггүй. Та нар дээр хийгдэж байгаа ажил та нарт төрөлхөөсөө байдаг зүйлийг харгалзан үздэг. Хүмүүсээс Миний шаарддаг зүйл хязгаар дотор тодорхойлогддог. Хэрвээ та нар сэхээтнүүдийн ярьдаг хэв маяг, дууны өнгөөр ярьж хэвшвэл энэ нь нэмэргүй; та нар ингэж чадахгүй. Хэв чанарыг чинь харгалзан үзвэл, та нар ядаж л мэргэн ухаан, эв дүйтэй ярьж, аливааг тодорхой, ойлгомжтой байдлаар тайлбарлаж чаддаг байх ёстой. Шаардлага хангахад энэ л хэрэгтэй. Хамгийн наад зах нь чи гүн ойлголт, эрүүл ухааныг олж авахад л болно. Яг одоо хамгийн чухал зүйл бол завхарсан сатанлаг зан чанараа хаях явдал юм. Өөрт чинь илэрдэг муу муухай байдлаа чи хаях ёстой. Тэдгээрийг хаяхгүй бол дээд зэргийн эрүүл ухаан, гүн ойлголтын талаар ярьж яаж чадах билээ? Эрин үе өөрчлөгдсөнийг хараад олон хүнд даруу зан, эсвэл тэвчээр байдаггүй бөгөөд тэдэнд ямар ч хайр, эсвэл ариун хүний төрх ч бас магад байдаггүй. Ийм хүмүүс ямар утгагүй гээч! Тэдэнд өчүүхэн төдий ч болов хэвийн хүн чанар бий гэж үү? Яриад байх гэрчлэл тэдэнд байдаг уу? Тэдэнд гүн ойлголт юм уу эрүүл ухаан огт байдаггүй. Мэдээж хүмүүсийн хэрэгжүүлэлтийн гажууд, алдаа мадагтай зарим талыг засаж залруулах хэрэгтэй; жишээ нь, урьдын хатуу чанд сүнслэг амьдрал, хөшүүн, мунхаг гадаад төрх зэрэг нь бүгд өөрчлөгдөх ёстой. Өөрчлөх гэдэг нь замбараагүй болох юм уу махан биед ташуурч, юу хүссэнээ хэлнэ гэсэн үг биш. Чи сул задгай ярих ёсгүй. Хэвийн хүн шиг ярьж, биеэ авч явна гэдэг нь уялдаа холбоотой ярьж, “тийм” гэвэл “тийм”, “үгүй” гэвэл “үгүй” л гэдэг байхыг хэлнэ. Баримтад тулгуурлаж, зохих ёсоор ярь. Бүү хуур, бүү худал хэл. Зан чанарын өөрчлөлттэй холбоотойгоор хэвийн хүний хүрч болох хязгаарыг ойлгох ёстой. Эс бөгөөс, чи бодит байдал руу орж чадахгүй.

МОАБЫН ҮР УДМЫГ АВРАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Энэ хоёроос гурван жилийн ажилд, та нар дээр хийгдсэн шүүлтийн ажлаар биелэх ёстой байсан зүйл үндсэндээ биелсэн. Ихэнх хүмүүс хэтийн ирээдүй болон хувь заяаныхаа заримыг орхисон. Гэсэн ч та нар бол Моабын үр удам гэдгийг дурдах үед олон хүн үүнийг тэвчиж чаддаггүй—зүс царай чинь үрчийж, ам чинь

мурийж, нүд чинь гөлийдөг. Та нар зүгээр л Моабын үр удам гэдэгтээ итгэж чаддаггүй. Моаб хараагдсаныхаа дараа энэ газар нутагт цөлөгдсөн. Түүний үр сад өнөөдрийг хүртэл удам угсааг нь залгамжилсан ба та нар бүгд түүний үр удам юм. Би яаж ч чадахгүй—хэн чамайг Моабын гэрт төр гэсэн юм бэ? Би чамайг өрөвддөг бөгөөд чамайг ийм байгаасай гэж хүсдэггүй боловч бодит баримтыг хэн ч өөрчилж чадахгүй. Чи бол Моабын үр удам бөгөөд Би чамайг Давидын үр удам гэж хэлж чадахгүй. Хэний үр удам байх чинь хамаагүй, чи бол мөн л нэг бүтээгдсэн зүйл, гэхдээ дорд байр суурьтай бүтээл, дорд гаралтай бүтээл юм. Бүх бүтээгдсэн зүйл Бурханы бүх ажлыг туулах ёстой; тэд бүгд Түүний байлдан дагуулалтын бай бөгөөд бүгд Түүний зөвт зан чанарыг харж, Түүний мэргэн ухаан, бүхнийг чадагч байдлыг мэдрэх ёстой. Одоо чи Моабын үр удам бөгөөд энэхүү шүүлт, гэсгээлтийг хүлээн авах ёстой; чи Моабын үр удам биш байсан ч энэ шүүлт, гэсгээлтийг бас л хүлээн авах хэрэгтэй бус уу? Үүнийг танин мэд! Үнэндээ, өнөөдөр Моабын үр удам дээр ажиллах нь хамгийн үнэ цэнтэй, хамгийн ач холбогдолтой зүйл юм. Ажил та нар дээр хийгдэж байгаа тул энэ нь хэмжээлшгүй их ач холбогдолтой. Хэрвээ уг ажил Хамын үр удам дээр хийгдсэн бол ач холбогдолгүй байх байв, учир нь Моабаас ялгаатай нь тэд тийм ч дорд гаралтай биш юм. Ноагийн хоёр дахь хүү Хамын үр удам зөвхөн хараагдсан—тэд садар самуунаас гараагүй юм. Ноа тэднийг боолын боол болог гэж хараасан учраас тэд ердөө л дорд байр суурьтай. Тэд дорд байр суурьтай боловч анхдагч үнэ цэн нь дорд байгаагүй. Моабын талаар ярих юм бол, тэр садар самуунаас төрсөн учраас анхнаасаа дорд байр суурьтай байсан гэдгийг хүмүүс мэднэ. Хэдийгээр Лотын байр суурь маш өндөр байсан боловч Моаб, Лот болон түүний охин хоёрын дундаас гарсан. Лот зөв шударга гэж нэрлэгдсэн боловч Моаб мөн л хараагдсан байв. Моаб дорд үнэ цэнтэй, дорд байр суурьтай байсан бөгөөд хараагдаагүй байсан ч гэсэн бузар заваанаас гарсан хэвээр тул Хамаас өөр байсан юм. Тэр Еховаг таниагүй, харин ч Еховаг эсэргүүцэж, Түүний эсрэг тэрсэлсэн—иймээс хамгийн харанхуй газарт унасан билээ. Одоо Моабын үр удам дээр ажиллах нь хамгийн харанхуйд унасан хүмүүсийг аврахын төлөө байдаг. Хэдий тэд хараагдсан ч Бурхан тэднээс алдрыг олж авахыг хүсэж байгаа, учир нь анхнаасаа тэд бүгд зүрх сэтгэлдээ Бурханаар дутагдсан хүмүүс байсан; зүрх сэтгэлдээ Бурхангүй хүмүүсийг Түүнийг дуулгавартай дагадаг, хайрладаг хүмүүс болгох нь л жинхэнэ байлдан дагуулалт бөгөөд тийм ажлын үр дүн хамгийн үнэ цэнтэй, хамгийн үнэмшилтэй байдаг. Зөвхөн энэ л алдрыг олж авах явдал—энэ бол эцсийн өдрүүдэд Бурханы олж авахыг хүсдэг алдар юм. Хэдий энэ хүмүүс дорд байр суурьтай ч одоо ийм агуу авралыг хүртэж чаддаг нь үнэхээр Бурханы өргөлт билээ. Энэхүү ажил маш утга учиртай бөгөөд шүүлтээр дамжуулан Тэр энэ хүмүүсийг олж авдаг. Түүний санаа зорилго нь тэднийг шийтгэхийн төлөө биш, харин аврахын төлөө байдаг. Хэрвээ эцсийн өдрүүдэд Тэрээр байлдан дагуулалтын ажлыг Израильд явуулсаар байсан бол энэ нь үнэ цэнгүй байх байв; үр дүнтэй байсан ч гэсэн ямар ч үнэ цэнгүй, эсвэл ямар нэгэн агуу ач холбогдолгүй

байх байсан ба Тэрээр бүх алдрыг олж авч чадахгүй байх байсан юм. Тэрээр хамгийн харанхуй газарт унасан, хамгийн хоцрогдсон хүмүүс та нар дээр ажиллаж байгаа. Энэ хүмүүс Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй ба Бурхан байдаг гэдгийг хэзээ ч мэдээгүй. Эдгээр бүтээл Бурханыг мартах хэмжээнд хүртлээ Сатанаар завхруулагдсан. Тэднийг Сатан сохолсон бөгөөд тэнгэрт Бурхан байдаг гэдгийг тэд огтхон ч мэддэггүй. Зүрх сэтгэлдээ та нар бүгд хуурамч шүтээн шүтдэг, Сатаныг шүтдэг—та нар хамгийн дорд, хамгийн хоцрогдсон хүмүүс биш гэж үү? Та нар бол ямар ч хувийн эрх чөлөөгүй, хамгийн дорд махан бие бөгөөд бас зовлон бэрхшээл туулдаг. Та нар бас энэ нийгмийн хамгийн доод түвшний хүмүүс бөгөөд бүр итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө ч байдаггүй. Та нар дээр ажиллахын ач холбогдол энд оршдог. Моабын үр удам болох та нар дээр өнөөдөр ажиллаж байгаа нь та нарыг доромжлохын төлөө байдаггүй, харин ажлын ач холбогдлыг илчлэхийн төлөө байдаг. Та нарын хувьд энэ нь асар их өргөлт юм. Хэрвээ хүн эрүүл ухаантай, мэдлэг ухаантай бол ингэж хэлнэ: “Би бол Моабын үр удам, өнөөдөр Бурханаас ийм агуу өргөлт, ийм агуу ерөөлийг хүртэхэд үнэхээр тохирохгүй. Миний хэлдэг, хийдэг зүйлд, мөн миний байр суурь, үнэ цэнд үндэслэвэл би Бурханы ийм агуу ерөөлийг хүртэхэд огт тохирохгүй. Израильчуудад Бурханыг гэх агуу хайр байдаг ба эдэлдэг нигүүлслийг нь Бурхан тэдэнд хайрладаг боловч тэдний байр суурь биднийхээс хамаагүй илүү өндөр. Абрахам Еховад маш үнэнч байсан ба Петр Есүст маш үнэнч байсан—тэдний үнэнч сэтгэл биднийхээс зуу дахин илүү. Үйлдэлд маань үндэслэвэл бид Бурханы нигүүлслийг эдлэх ямар ч үнэ цэнгүй.” Хятад дахь энэ хүмүүсийн үйлчлэлийг Бурханы өмнө авчирч ердөө болохгүй. Энэ нь бүрэн эмх замбараагүй; одоо Бурханы маш их нигүүлслийг эдэлж байгаа чинь гагцхүү Бурханы өргөлт юм! Та нар хэзээ Бурханы ажлыг эрж хайсан юм бэ? Та нар хэзээ өөрийнхөө амийг Бурханы төлөө золиосолсон юм бэ? Хэзээ та нар гэр бүл, эцэг эх, хүүхдүүдээ дуртайяа орхисон юм бэ? Та нарын хэн ч асар их төлөөс төлөөгүй! Хэрвээ Ариун Сүнс чамайг гаргаж ирээгүй бол та нарын хэчнээн нь бүх зүйлээ золиосолж чадах байсан бэ? Та нарыг хүчилж, албадсан учраас л өнөөдрийг хүртэл дагасан. Та нарын үнэнч зан хаана байна вэ? Дуулгавартай байдал чинь хаана байна вэ? Үйлдэлд чинь суурилсан бол та нарыг аль хэдийн устгаж, бүгдийг нь арчин хаях ёстой байсан юм. Та нар тийм агуу ерөөлийг хүртэх ямар эрхтэй юм бэ? Та нар өчүүхэн ч үнэ цэнгүй! Та нарын дундаас хэн өөрийнхөө замыг зассан юм бэ? Та нарын дундаас хэн өөрөө үнэн замыг олсон юм бэ? Та нар бүгд залхуу, ховдог шунахай, тав тух хайсан олиггүй амьтад! Та нар өөрсдийгөө агуу гэж бодож байна уу? Та нарт онгирох юм юу байна вэ? Моабын үр удам гэдгийг чинь үл ойшоосон ч гэсэн, та нарын уг чанар, эсвэл та нарын төрсөн газар хамгийн өндөр дээд гэж үү? Түүний үр удам гэдгийг чинь үл ойшоосон ч гэсэн, та нар бүгд тэр чигтээ Моабын үр удам биш гэж үү? Бодит үнэнийг өөрчилж болно гэж үү? Та нарын уг чанарыг одоо илчлэх нь бодит үнэнийг гуйвуулна гэж үү? Та нар боол шиг зангаа, амьдралаа, мөн ёс жудгаа хар—та нар

хүн төрөлхтний дундах дорд хүмүүсээс ч долоон дор гэдгээ мэдэхгүй гэж үү? Та нарт онгирох зүйл юу байна вэ? Нийгэм дэх байр сууриа хар. Та нар хамгийн доод түвшнийх биш гэж үү? Та нар Намайг буруу ярилаа гэж бодож байна уу? Абрахам Исаакыг тахил болгосон—та нар юу өргөн барьсан юм бэ? Иов бүх зүйлээ өргөн барьсан—та нар юу өргөн барьсан юм бэ? Маш олон хүн үнэн замыг эрж хайхын тулд өөрсдийн амийг өгч, толгойгоо бөхийн, цусаа урсгасан. Та нар тийм төлөөс төлсөн үү? Харьцуулж үзвэл та нарт ийм агуу нигүүлслийг эдлэх эрх огт байхгүй. Өнөөдөр та нарыг Моабын үр удам гэж хэлэх нь буруу гэж үү? Өөрсдийгөө хэтэрхий өндрөөр бүү авч үз. Чамд онгирох юм юу ч байхгүй. Тийм агуу аврал, тийм агуу нигүүлсэл та нарт чөлөөтэй өгөгдсөн. Та нар юу ч золиослоогүй атлаа нигүүлслийг чөлөөтэй эдэлсэн. Та нар ичихгүй байна уу? Энэ үнэн зам та нарын өөрсдөө эрж хайж, олж авсан зүйл мөн үү? Үүнийг хүлээн зөвшөөрөхөд Ариун Сүнс та нарыг хүчлээгүй гэж үү? Та нарт эрж хайсан зүрх сэтгэл хэзээ ч байгаагүй, үнэнийг эрж хайх, хүсэн эрмэлзэх зүрх сэтгэл бүр ч байгаагүй. Та нар зүгээр л хойш сууж, үүнийг эдэлсээр ирсэн; өчүүхэн ч хичээл чармайлт гаргахгүйгээр энэ үнэнийг олж авсан. Та нар гомдоллох ямар эрхтэй юм бэ? Чи өөрийгөө хамгийн их үнэ цэнтэй гэж бодож байна уу? Амиа золиосолж, цусаа урсгасан хүмүүстэй харьцуулбал та нарт гомдоллох юм юу байна вэ? Та нарыг яг одоо устгах нь зөв зүйтэй, жам ёсны хэрэг! Дуулгавартай байж, дагахаас өөр ямар ч сонголт та нарт байхгүй. Та нар зүгээр л үнэ цэнгүй! Та нарын дундаас ихэнх нь дуудагдсан боловч хэрвээ орчин чинь албадан хүчлээгүй, эсвэл та нарыг дуудагдахад хүргээгүй байсан бол та нар гарч ирэх бүр дургүй байх байсан. Хэн ингэж татгалзахыг хүсэж байна вэ? Хэн бие махбодын зугаа цэнгэлийг хаяхыг хүсэж байна вэ? Та нар бүгд тав тухтай байдалд шунан баясдаг, тансаг амьдралыг эрж хайдаг хүмүүс! Та нар ийм агуу ерөөл олж авсан—та нар өөр юу хэлэх гэсэн юм бэ? Та нарт ямар гомдол байна вэ? Та нар тэнгэр дэх хамгийн агуу ерөөл, хамгийн агуу нигүүлслийг эдлэх боломжтой болсон бөгөөд газар дэлхий дээр өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажил өнөөдөр та нарт илчлэгдсэн. Энэ нь ерөөл биш гэж үү? Бурханыг эсэргүүцэж, Түүний эсрэг тэрсэлсэн учраас та нар одоо ингэж гэсгээгдэж байгаа. Энэ гэсгээлтийн улмаас та нар Бурханы өршөөл, хайрыг харсан ба Түүний зөвт, ариун байдлыг бүр ч их харсан. Энэхүү гэсгээлтийн улмаас, мөн хүн төрөлхтний бузар заваан байдлын улмаас та нар Бурханы агуу хүч чадлыг харж, Түүний ариун, агуу байдлыг харсан билээ. Энэ нь хамгийн ховор үнэн биш гэж үү? Энэ нь утга учиртай амьдрал биш гэж үү? Бурханы хийдэг ажил утга учраар дүүрэн байдаг! Иймээс та нарын байр суурь хэдий чинээ доогуур байна, Бурханаар өргөгдсөн гэдгийг чинь төдий чинээ их нотолдог ба та нар дээрх Түүний өнөөдрийн ажлын асар их үнэ цэнийг төдий чинээ их баталдаг. Энэ нь ердөө өөр хаанаас ч олж авах аргагүй, үнэлж баршгүй эрдэнэс юм! Эрин үеүдийн туршид хэн ч ийм агуу авралыг эдлээгүй. Та нарын байр суурь дорд хэмээх баримт нь Бурханы аврал хэчнээн агуу болохыг харуулдаг бөгөөд Бурхан хүн төрөлхтөнд үнэнч гэдгийг харуулдаг—Тэр устгадаг биш, авардаг билээ.

Хятад хүмүүс Бурханд хэзээ ч итгээгүй; тэд Еховад хэзээ ч үйлчлээгүй, Есүст хэзээ ч үйлчлээгүй. Тэд бөхөлзөж, хүж асааж, сахиустай цаас шатааж, Буддаг шүтэж л чадна. Тэд зүгээр л хуурамч шүтээн шүтдэг—тэд бүгд туйлын тэрслүү. Иймээс хүмүүсийн байр суурь доогуур байх тусам, та нараас Бурханы олж авдаг зүйл бүр ч их алдар суу юм гэдгийг энэ нь төдий чинээ их харуулдаг. Зарим нь өөрсдийнхөө үзэл бодлын үүднээс: “Бурхан минь, Таны хийдэг ажил юу юм бэ? Ийм өндөр дээд, ийм ариун Бурхан Та бузар заваан газарт ирдэг гэж үү? Та Өөрийгөө ийм доогуур үздэг гэж үү? Бид маш бузар заваан боловч Та бидэнтэй хамт байхыг хүсэж байна уу? Та бидний дунд амьдрахад бэлэн үү? Бид ийм дорд байр суурьтай байхад Та биднийг бүрэн төгс болгохыг хүсэж байна уу? Та биднийг үлгэр жишээ, загвар болгон ашиглах уу?” гэж хэлж болох юм. Би ингэж хэлдэг: Чи Миний хүслийг ойлгодоггүй. Чи Миний хийхийг хүсдэг ажлыг ойлгодоггүй, Миний зан чанарыг ч ойлгодоггүй. Миний хийх гэж байгаа ажлын ач холбогдолд чиний чадвараар хүрэх аргагүй. Миний ажил хүний үзэлтэй нийцэж болох уу? Хүний үзлээр бол Би өндөр дээд байр суурьтай гэдгээ харуулж, асар их үнэ цэнтэй гэдгээ харуулж, Өөрийн нэр хүнд, ариун, агуу байдлыг харуулахын тулд сайхан оронд төрөх ёстой байсан. Хэрвээ Би Намайг хүлээн зөвшөөрдөг газарт, өндөр түвшний гэр бүлд төрсөн бол, хэрвээ Би өндөр байр суурь, албан тушаалтай байсан бол Надад маш сайн хандах байсан. Тэр нь Миний ажилд ямар ч ашиггүй байх байсан бөгөөд тэгвэл ийм агуу аврал илчлэгдэж мөн л чадна гэж үү? Намайг хардаг бүхэн Надад дуулгавартай байж, бузар заваанаар бохирдоогүй байна. Би тийм газарт төрөх ёстой байсан юм. Тэр бол та нарын боддог зүйл. Гэхдээ энэ талаар бодоод үз: Бурхан газар дээр зугаа цэнгэлийн төлөө ирсэн үү, эсвэл ажлын төлөө ирсэн үү? Хэрвээ Би тийм амархан, тав тухтай газарт ажилласан бол Өөрийн бүрэн алдрыг олж авч чадах байсан уу? Би Өөрийн бүх бүтээлийг байлдан дагуулж чадах уу? Бурхан газар дээр ирэх үедээ энэ дэлхийнх биш байсан бөгөөд дэлхий ертөнцөд зугаацахын тулд бие махбодтой болоогүй. Ажиллаж буй нь Түүний зан чанарыг хамгийн сайн илчлэх, хамгийн утга учиртай газар бол Түүний төрсөн газар юм. Энэ нь ариун, эсвэл бузар заваан газар байх нь хамаагүй, мөн Тэр хаана ажиллаж байгаа нь хамаагүй Тэр бол ариун юм. Дэлхий ертөнц дээрх бүх зүйлийг Тэр бүтээсэн, гэхдээ бүгдийг нь Сатан завхруулсан билээ. Гэсэн ч бүх зүйл Түүнд харьяалагддаг хэвээр байгаа; тэд бүгд Түүний гарт байдаг. Тэр ариун байдлаа илчлэхийн төлөө бузар газарт ирж, тэндээ ажилладаг; Тэр үүнийг Өөрийн ажлын төлөө л хийдэг, өөрөөр хэлбэл, Тэр энэхүү бузар газрын хүмүүсийг аврахын төлөө ийм ажил хийхдээ асар их доромжлол туулдаг. Энэ нь гэрчлэл хийхийн тулд, бүх хүн төрөлхтний төлөө хийгддэг. Ийм ажил хүмүүст Бурханы зөвт байдлыг харуулдаг бөгөөд энэ нь Бурханы дээдийн дээд байдлыг илүү сайн харуулж чаддаг. Бусдын зэвүүцэн жигшдэг бүлэг дорд хүмүүсийг аврах авралаас Түүний агуу, шулуун шударга байдал харагддаг. Бузар заваан газарт төрсөн нь Тэр бол дорд гэдгийг огтхон ч нотолдоггүй; энэ нь ердөө, Түүний агуу байдал болон хүн төрөлхтнийг гэх Түүний

жинхэнэ хайрыг харах боломжийг бүх бүтээлд олгодог. Тэр хэдий чинээ ингэж хийнэ, энэ нь хүнийг гэсэн Түүний ариун хайрыг, Түүний өө сэвгүй хайрыг төдий чинээ их илчилдэг. Бурхан бол ариун агаад зөвт. Тэр бузар газарт төрсөн хэдий ч, мөн Нигүүлслийн эрин үед Есүс нүгэлтнүүдтэй хамт амьдарч байсны адилаар бузар заваан байдлаар дүүрэн хүмүүстэй хамт амьдардаг хэдий ч Түүний бүхий л ажил бүх хүн төрөлхтний оршин тогтнолын төлөө хийгддэг бус уу? Энэ нь бүхэлдээ, хүн төрөлхтөн агуу авралыг олж авахын төлөө байдаггүй гэж үү? Хоёр мянган жилийн өмнө Тэр хэдэн жилийн турш нүгэлтнүүдтэй хамт амьдарсан. Тэр нь золин авралын төлөө байсан юм. Өнөөдөр Тэр бузар заваан, дорд бүлэг хүмүүстэй хамт амьдарч байгаа. Энэ нь авралын төлөө байдаг. Түүний бүхий л ажил хүмүүс та нарын төлөө биш гэж үү? Хэрвээ хүн төрөлхтнийг аврахын төлөө байгаагүй бол тэжээлийн онгоцонд төрснийхөө дараа Тэр яагаад нүгэлтнүүдтэй хамт маш олон жилийн турш амьдарч, зовсон юм бэ? Хэрвээ хүн төрөлхтнийг аврахын төлөө байгаагүй бол Тэр яагаад хоёр дахь удаагаа бие махбодод эргэн ирж, чөтгөрүүдийн цуглардаг энэ газар нутагт төрж, Сатаны гүнзгий ялзруулсан энэ хүмүүстэй хамт амьдрах юм бэ? Бурхан итгэмжит биш гэж үү? Түүний ажлын аль хэсэг нь хүн төрөлхтний төлөө байгаагүй вэ? Аль хэсэг нь та нарын хувь заяаны төлөө байгаагүй вэ? Бурхан бол ариун—энэ нь хувиршгүй! Хэдий Тэр бузар заваан газар нутагт ирсэн боловч бузар заваанаар бохирдоогүй; энэ бүхэн нь, хүн төрөлхтнийг гэх Бурханы хайр туйлын аминч бус бөгөөд Түүний туулдаг зовлон, доромжлол туйлын их л гэсэн үг юм! Та бүхний төлөө, та нарын хувь заяаны төлөө Тэр хэр их доромжлол амсдагийг та нар мэдэхгүй гэж үү? Тэр агуу хүмүүс юм уу баян, хүчирхэг гэр бүлийн хөвгүүдийг аврахын оронд дорд агаад бусдын үл тоодог хүмүүсийг онцгойлон авардаг. Энэ бүхэн нь Түүний ариун байдал биш гэж үү? Энэ бүхэн нь Түүний зөвт байдал биш гэж үү? Бүх хүн төрөлхтний оршин тогтнолын төлөө Тэр бузар заваан газарт төрж, доромжлол бүрийг амсахыг илүүд үзнэ. Бурхан бол маш бодитой—Тэр ямар ч хуурамч ажил хийдэггүй. Ажлын үе шат бүр ийм бодитой байдлаар хийгддэггүй гэж үү? Хэдийгээр хүмүүс бүгд Түүнийг гүжирдэж, Тэр нүгэлтнүүдтэй хамт нэг ширээнд суудаг гэж хэлж, бүгдээрээ Түүнийг дооглож, Түүнийг бузар хөвгүүдтэй, хамгийн дорд хүмүүстэй хамт амьдардаг гэж хэлдэг ч гэсэн Тэр Өөрийгөө амь бие хайргүйгээр зориулсаар байж, улмаар хүн төрөлхтний дунд гологдсоор байдаг. Түүний туулдаг зовлон та нарынхаас илүү их биш гэж үү? Түүний ажил та нарын төлсөн төлөөснөөс их биш гэж үү? Та нар бузар газар нутагт төрсөн атлаа Бурханы ариун байдлыг олж авсан. Та нар чөтгөрүүдийн цуглардаг газар нутагт төрсөн атлаа агуу их хамгаалалт хүлээн авсан. Та нарт ямар сонголт байгаа юм бэ? Та нарт ямар гомдол байгаа юм бэ? Түүний туулсан зовлон та нарын туулсан зовлонгоос хавьгүй их биш гэж үү? Тэр газар дээр ирсэн бөгөөд хүний ертөнцийн баяр цэнгэлийг хэзээ ч эдлээгүй. Тэр тийм зүйлийг жигшдэг. Бурхан хүнээс материаллаг үр ашгийг эдлэхээр газар дээр ирээгүй, мөн хүний хоол хүнс, хувцас хунар, гоёл чимэглэлийг эдлэхээр ч ирээгүй. Тэр эдгээр зүйлийг огт

тоодоггүй. Тэр газар дэлхийн эд хөрөнгийг эдлэхийн төлөө биш, харин хүний төлөө зовохын тулд газар дээр ирсэн. Тэр зовохын тулд, ажиллахын тулд, Өөрийн удирдлагын төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн тулд ирсэн. Тэр сайхан газар сонгож, элчин сайдын яаманд юм уу тансаг зочид буудалд амьдраагүй, Өөрт нь үйлчлэх өдий төдий зарц нар ч Түүнд байгаагүй. Өөрсдийнхөө харсан зүйлээс та нар Тэр ажиллахаар ирсэн үү, эсвэл зугаацахаар ирсэн үү гэдгийг мэдэхгүй гэж үү? Нүд чинь хардаггүй юм уу? Тэр та нарт хэр ихийг өгсөн бэ? Хэрвээ Тэр тав тухтай газар төрсөн бол алдрыг олж авч чадах байсан уу? Ажиллаж чадах байсан уу? Тийнхүү хийх нь ямар нэгэн ач холбогдолтой байх байсан уу? Тэр хүн төрөлхтнийг бүрмөсөн байлдан дагуулж чадах байсан уу? Хүмүүсийг бузар газар нутгаас аварч чадах байсан уу? Хүмүүс өөрсдийнхөө үзлээр ингэж асуудаг: “Бурхан ариун байж яагаад бидний энэ бузар газарт төрсөн юм бэ? Та бузар хүмүүс биднийг үзэн ядаж, жигшдэг; Та бидний эсэргүүцэл, тэрслүү байдлыг жигшдэг, тэгвэл яагаад бидэнтэй хамт амьдардаг юм бэ? Та бол өндөр дээд Бурхан. Та хаа ч төрж болох байтал яагаад заавал энэ бузар газарт төрсөн юм бэ? Та биднийг өдөр болгон гэсгээж, шүүдэг бөгөөд Моабын үр удам гэдгийг маань тодорхой мэддэг, тэгвэл Та яагаад бидний дунд амьдарсаар байдаг юм бэ? Яагаад Та Моабын үр удмын гэр бүлд төрсөн юм бэ? Яагаад Та тэгсэн юм бэ?” Та нарын ийм ойлголт тэр чигтээ эрүүл ухаанаар дутмаг! Зөвхөн ийм ажил л хүмүүст, Түүний агуу байдлыг, Түүний даруу төлөв, нууцлаг байдлыг харах боломж олгодог. Тэр Өөрийн ажлын төлөө бүхнийг золиослоход бэлэн байдаг бөгөөд Өөрийн ажлын төлөө бүх зовлонг туулсан. Тэр үүнийг хүн төрөлхтний төлөө хийдэг, үүнээс ч илүүтэйгээр Сатаныг байлдан дагуулахын төлөө хийдэг болохоор бүх бүтээл Түүний эрх мэдэлд захирагдаж болох юм. Зөвхөн энэ л утга учиртай, үнэ цэнтэй ажил. Хэрвээ Иаковын үр удам Хятадад, энэ хэсэг газар нутагт төрсөн байгаад, тэдгээр нь та бүхэн байсан бол та нар дээр хийсэн ажлын ач холбогдол юу байх байсан бэ? Сатан юу гэж хэлэх байсан бэ? “Тэд өмнө нь Танаас эмээдэг байсан, тэд анхнаасаа Танд дуулгавартай байсан ба тэдэнд Танаас урваж байсан түүх байхгүй. Тэд хүн төрөлхтнөөс хамгийн харанхуй, хамгийн дорд, хамгийн хоцрогдмол нь биш” гэж Сатан хэлэх байсан. Хэрвээ ажил үнэхээр ийм маягаар хийгдсэн бол хэн үүнд үнэмших юм бэ? Бүхий л орчлон ертөнцөд хятадууд бол хамгийн хоцрогдсон хүмүүс. Тэд ёс жудаг багатай ядуу дорд төрсөн; тэд мангуу, хөшүүн бөгөөд бүдүүлэг, доройтмол. Тэдэнд сатанлаг зан чанар нэвт шингэсэн, бузар агаад садар самуун. Та нарт энэ бүх сатанлаг зан чанар байдаг. Энэ ажил дуусмагц хүмүүс эдгээр завхарсан зан чанарыг хаяж, бүрмөсөн дуулгавартай байж, бүрэн төгс болгуулж чадна. Ажлын ийм үр дүн л бүтээлийн дундах гэрчлэл юм! Гэрчлэл гэж юу болохыг чи ойлгов уу? Гэрчлэлийг үнэндээ яаж хийх ёстой вэ? Ийм төрлийн ажил нь та нарыг товойлгогч, мөн түүнчлэн хүчин зүтгэгч болгосон; тэр ч бүү хэл, энэ нь та нарыг авралын бай болгосон. Өнөөдөр та нар Бурханы ардууд; хожим та нар үлгэр дуурайл, загвар болно. Энэ ажилд та нар янз бүрийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд эцэст нь та нар

авралын бай болно. Олон хүн үүнээс болж сөрөг болдог; тэд туйлын сохор биш гэж үү? Чи юуг ч тодорхой харж чаддаггүй! Ингэж нэрлэх төдий нь л чамайг гонсойлгодог уу? Бурханы зөвт зан чанар гэж юу болохыг чи ойлгож байна уу? Бурханы аврал гэж юу болохыг ойлгож байна уу? Бурханы хайр гэж юу болохыг чи ойлгож байна уу? Чамд ямар ч ёс жудаг байхгүй! Чамайг сайхнаар хэлэх үед чи баярладаг. Муугаар хэлэх үед чи дургүй болж, ухарч няцдаг. Чи юу юм бэ? Чи үнэн замыг эрэлхийлэхгүй байна! Яг одоо эрж хайхаа боль—ичгүүртэй юм! Маш ялихгүй зүйл чамайг гонсойлгодог нь ичгүүрийн тэмдэг биш гэж үү?

Чи өөрийгөө бага зэрэг мэддэг байсан нь дээр. Өөрийгөө хэтэрхий өндрөөр бүү бод, бас тэнгэр лүү явах талаар бүү мөрөөд—зүгээр л газар дээр байлдан дагуулагдахаар үнэнч шударгаар хичээ. Оршин байдаггүй тэдгээр бодитой бус мөрөөдлийн талаар бүү бод! Хэн нэгэн хүн: “Хэдийгээр би Моабын үр удам боловч Бурханы төлөө чармайхыг хүсэж байна. Би хуучин өвөг дээдсээсээ нүүр буруулна! Тэр намайг төрүүлсэн, бас над дээр гишгэлсэн, одоог хүртэл би харанхуйд амьдарсаар байгаа. Өнөөдөр Бурхан намайг чөлөөлж, би эцэст нь тэнгэрнарыг харсан. Бурханы илчлэлтээр дамжуулан би Моабын үр удам гэдгээ эцэст нь харсан. Хөгшин Сатан намайг сохолсон байсан учраас өмнө нь би нүдэндээ халхавчтай байж, Бурхан маш их ажил хийснийг мэдээгүй. Би түүнээс нүүр буруулж, түүнийг нэгд нэггүй шившиглэх болно!” гэж хэлэх юм бол энэ нь шийдвэртэй, ноён нуруутай хүний үг юм. Тэгвэл та нарт ийм шийдвэр байгаа юу? Та нар дор бүрнээ хүн шиг харагддаг чинь хамаагүй, өөр хэнээс ч илүү хурдан нуран унадаг бөгөөд энэ хэрэг явдал дээр хамгийн мэдрэмтгий байдаг. Моабын үр удам гэдгийг чинь дурдмагц та нарын ам цорвойн мурийдаг. Энэ нь гахайны зан чанар биш гэж үү? Үнэ цэнгүй юм. Та нар өөрсдийн нэр алдар, эд баялгийн төлөө амиа золиослоход бэлэн байдаг! Чи Моабын үр удам байхыг хүсдэггүй байж болох ч мөн биз дээ? Чи мөн бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрөх ёстой гэдгийг чинь Би өнөөдөр хэлж байна. Би баримтаас зөрж ярьдаггүй. Зарим хүн үүнээс болж сөрөг болдог, гэхдээ сөрөг байх юм юу байна? Чи бас агуу улаан лууны үр хүүхэд биш гэж үү? Чамайг Моабын үр удам гэж хэлэх нь шударга бус гэж үү? Чи дотроо болон гаднаа юуг амьдран харуулж байгаагаа хар. Хөлөөс толгой хүртэл чинь бардамнах зүйл юу ч үгүй. Садар самуун байдал, бузар заваан, харалган байдал, эсэргүүцэл, тэрслүү байдал—эдгээр нь бүгд чиний зан чанарын хэсгүүд биш гэж үү? Чи үргэлж садар самуун газар нутагт амьдардаг бөгөөд чамд хийгээгүй муу муухай гэж байхгүй. Чи өөрийгөө гайхалтай ариун гэж боддог. Хийсэн зүйлсээ хараад өөртөө тун сэтгэл хангалуун байдаг. Чи магтууштай юу хийсэн юм бэ? Та нар араатнуудтай адилхан. Ямар ч хүн чанаргүй! Та нар амьтадтай хамт амьдарч, ёрын муу, садар самуун санаа бодол дунд амьдардаг. Хүмүүс та нарт хэр их зүйл дутагддаг вэ? Та нар агуу улаан лууны хүүхдүүд гэдгээ зөвшөөрдөг бөгөөд үйлчлэл үзүүлэхэд бэлэн байдаг боловч дараа нь Моабын үр удам гэдгийг чинь хэлэх үед сөрөг болдог. Энэ нь үнэн биш гэж үү? Яг л эцэг эхээсээ төрдөгтэй чинь адилхан—тэд хэчнээн

аймшгийн байх нь хамаагүй чи тэднээс л төрсөн байдаг. Чи өргөж авсан ээжтэй болоод, гэрээсээ явсан ч гэсэн төрсөн эцэг эхийнхээ хүүхэд нь хэвээр байх бус уу? Тэр баримтыг өөрчилж болох уу? Би чамайг шалтгаангүйгээр Моабын үр удам гэж нэрлэсэн үү? Зарим хүн: “Та намайг зүгээр л өөрөөр нэрлэж болохгүй юу?” гэдэг. “Би чамайг товойлгогч гэж нэрлэвэл ямар вэ?” гэж Би хэлсэн. Тэд бас товойлгогч байхыг ч хүсдэггүй. Тэгвэл чи юу байхыг хүсэж байна вэ? Товойлгогчид, үйлчлэл үзүүлэгчид—энэ та нар биш гэж үү? Чи өөр юу сонгох юм бэ? Чи агуу улаан лууны улс оронд төрсөн хүн биш гэж үү? Чи өөрийгөө Давидын үр хүүхэд гэж хэчнээн хэлэх нь хамаагүй, энэ нь баримттай нийцдэггүй. Энэ нь чиний өөрөө сонгодог зүйл мөн үү? Чи өөрийнхөө дуртай ямар нэг сайхан нэрийг өөртөө авч болох уу? Өмнө нь дурдсан агуу улаан лууны хүүхдүүд нь завхарсан хүмүүс та нар биш гэж үү? Үйлчлэл үзүүлэгчдийн тухайд бол—тэд ч бас завхарсан хүмүүс та нар биш гэж үү? Өмнө нь дурдсан байлдан дагуулагдсан загвар, үлгэр дуурайл—тэдгээр нь ч бас хүмүүс та нар биш гэж үү? Төгс болгуулах замыг та нарын төлөө хэлээгүй гэж үү? Гэсгээгдэж, шүүгддэг хүмүүс бол хүмүүс та нар юм; хожим төгс болгуулах хүмүүс ч бас та нарын зарим нь байх бус уу? Энэ нэр цол мөн л хамаатай гэж үү? Та нар үнэхээр эрүүл ухаангүй; тийм ялихгүй зүйлсийг ч тодорхой харж чадахгүй гэж үү? Чи хэн нь хэний үр удам бэ гэдгийг мэддэггүй боловч Би үүнийг тодорхой мэднэ, тэгээд та нарт хэлж байна. Үүнийг өнөөдөр танин мэдэж чадвал зүгээр. Өөрийгөө үргэлж бүү дорд үз. Чи хэдий чинээ сөрөг байж, ухарч няцна, Сатаны үр сад гэдгийг чинь энэ нь төдий чинээ их нотолно. Магтан дуу сонсгоход чинь, “Моабын үр удам магтан дуу сонсож болно гэж үү? Би үүнийг сонсохгүй; би тохирохгүй!” гэж хэлдэг хүмүүс бий. Хэрвээ чи тэднийг дуулуулбал тэд: “Хэрвээ Моабын үр удам дуулбал, Бурхан сонсохыг хүснэ гэж үү? Бурхан намайг жигшдэг. Би Бурханы өмнө очихдоо дэндүү их ичиж байна, би Түүний төлөө гэрчлэл хийж чадахгүй. Бурхан сонсоод уцаарлах вий гэсэндээ би зүгээр л дуулахгүй” гэдэг. Энэ нь сөрөг арга зам биш гэж үү? Бүтээгдсэн зүйл болохын хувьд чи садар самуун газар нутагт төрсөн бөгөөд агуу улаан лууны үр хүүхэд, Моабын үр удам юм; чи хуучин өвөг дээдсээсээ, мөн хөгшин Сатанаас нүүр буруулах ёстой. Ингэдэг хүн л Бурханыг үнэхээр хүсдэг нэгэн юм.

Анх Би та нарт Бурханы ардуудын байр суурийг өгөхөд та нар өөр хэнээс ч илүү баяр хөөртэйгөөр дээш доош үсэрч байсан. Гэвч, та нар бол Моабын үр удам гэж Намайг хэлэнгүүт яасан бэ? Та нар бүгд нуран унасан! Биеийн хэмжээ чинь хаана байна вэ? Байр суурийн талаарх та нарын үзэл баримтлал хэтэрхий хүчтэй! Ихэнх нь өөрсдийгөө өргөж чаддаггүй. Зарим нь бизнес хийхээр явдаг, зарим нь ажиллахаар явдаг. Та нар бол Моабын үр удам гэж Намайг хэлэнгүүт та нар бүгд зугтахыг хүсдэг. Энэ нь та нарын өдөржин хашхирдаг Бурханы төлөө гэрчлэл хийх явдал гэж үү? Ийм маягаар Сатан үнэмших үү? Энэ нь ичгүүрийн тэмдэг биш гэж үү? Та нарыг байлгах нь ямар хэрэгтэй юм бэ? Та нар бүгд хог новш! Та нар ямар зовлон туулсандаа ингэж их хэлмэгдсэн мэт та нарт санагддаг вэ? Бурхан та нарыг

тодорхой хэмжээнд тамламагцаа жаргалтай байж, зориуд та нарыг яллахаар ирсэн мэт байдаг бөгөөд та нарыг яллаж, устгасны дараа Түүний ажил дуусна гэж та нар боддог. Би ингэж хэлсэн гэж үү? Харалган байдлаасаа болоод та нар ингэж боддоггүй гэж үү? Та нар өөрсдөө сайн хийхээр мэрийхгүй байна уу, эсвэл Би санаатайгаар та нарыг ялладаг уу? Би хэзээ ч тэгээгүй—тэр бол та нарын бодож олсон зүйл. Би тийм байдлаар огтхон ч ажиллаагүй, Надад тийм санаа ч байхгүй. Хэрвээ Би үнэхээр та нарыг устгахыг хүссэн бол тийм зовлон бэрхшээл туулах хэрэгтэй байсан гэж үү? Хэрвээ Би үнэхээр та нарыг устгахыг хүссэн бол та нартай чин сэтгэлээсээ ярих хэрэгтэй байсан гэж үү? Миний хүсэл бол энэ: Би та нарыг аварсан цагт тэр нь Миний амрах үе байх болно. Хүн хэдий чинээ дорд байна, төдий чинээ Миний авралын бай юм. Та нар хэдий чинээ идэвх санаачилгатайгаар орж чадна, Би төдий чинээ аз жаргалтай байх болно. Та нар хэдий чинээ нурж унана, Би төдий чинээ сэтгэл гонсойно. Та нар үргэлж ихэмсэглэн алхаж, сэнтийд суухыг хүсдэг—гэхдээ тэр нь та нарыг бузраас аврах зам биш гэдгийг Би та нарт хэлье. Сэнтийд залрах тухай уран зөгнөл та нарыг төгс болгохгүй; тэр нь бодит биш. Би чамайг Моабын үр удам гэж хэлэхэд чи аз жаргалгүй болдог. Чи: “Та намайг ёроолгүй нүх рүү оруулбал би Таны төлөө гэрчлэл хийхгүй, эсвэл Таны төлөө зовохгүй” гэж хэлдэг. Ингэж байгаа чинь Намайг эсэргүүцэж байгаа хэрэг биш гэж үү? Ингэх нь чамд ашигтай юу? Би чамд маш их нигүүлсэл өгсөн—чи мартчихсан уу? Элбэрэлт эхийнх мэт Бурханы зүрх сэтгэлийг чи голж, доромжилсон; чиний хувьд үр дагавар нь ямар байх вэ? Миний төлөө гэрчлэл хийхгүй бол Би чамайг хүчлэхгүй, гэхдээ чи эцэстээ сүйрлийн бай болно гэдгээ мэдэх ёстой. Хэрвээ Би чамаас гэрчлэл олж авч чадахгүй бол үүнийг бусад хүмүүсээс олж авна. Тэр нь Надад хамаагүй боловч эцэстээ чи харамсана, тэр үед чи хэдийнээ харанхуйд унасан байх болно. Тэгвэл хэн чамайг аварч чадах юм бэ? Чамгүйгээр ажлыг хийж чадахгүй гэж бүү бод—чи байлаа гээд хэтэрхий олон болохгүй, чи байхгүй байлаа гээд бас хэтэрхий цөөдөхгүй. Өөрийгөө хэтэрхий хүндтэй гэж бүү үз. Хэрвээ чи Намайг дагахыг хүсэхгүй байгаа бол чи тэрслүү бөгөөд чамд ямар ч хүсүүштэй зүйл байхгүй гэдгийг энэ нь харуулдаг. Хэрвээ чи сайн ярьдаг бол тэр чинь зүгээр л, Өөрийн ажлаар дамжуулан Миний авчирсан үгээр өөрийгөө зэвсэглэснээс чинь болоогүй гэж үү? Чамд магтууштай юм юу байна вэ? Өөрийнхөө төсөөлөлд бүү эзэмдүүл! Хэрвээ Би Моабын үр удам та нараас алдрыг олж авч чадахгүй бол алдрыг олж авах хүртлээ Өөрийнхөө ажилд зориулан Моабын үр удмын хоёр дахь, гурав дахь бүлгийг сонгох болно. Хэрвээ чи Миний төлөө гэрчлэл хийх хүсэлгүй бол яв! Би хүчлэхгүй! Та наргүйгээр Би нэг ч алхам хөдөлж чадахгүй гэж бүү бод. Хятадын энэ газар нутгаас Миний ажилд тохиромжтой бай олох амархан. Энэ газар нутгаас өөр юу ч олдохгүй—бузар, завхарсан хүмүүс үнэхээр хаа сайгүй байгаа бөгөөд Миний ажил хаана ч хийгдэж болно. Их бардам бүү бай! Хэчнээн бардам байх чинь хамаагүй, чи садар самуунаас төрсөн хүүхэд хэвээр биш гэж үү? Өөрийнхөө үнэ цэнийг хар, чамд өөр

ямар сонголт байна вэ? Та нарт амьдрах боломж олгож байгаа төдий нь асар их өргөлт, иймээс та нар юундаа биеэ тооно вэ? Хэрвээ Миний ажил эрин үеийг төгсгөхийн төлөө байгаагүй бол чи аль хэдийн байгалийн гамшиг болон хүний бий болгосон гамшигт уначих байсан бус уу? Чи маш тав тухтай амьдарсаар байж чадах уу? Чи бас энэ хэрэг явдлын талаар байнга маргалддаг. Чамайг Моабын үр удам гэж хэлснээс минь хойш чи цаг ямагт урвайсаар байгаа. Чи суралцаж боловсордоггүй, Бурханы үгийг уншдаггүй бөгөөд энэ, тэр хүнийг харж тэвчдэггүй. Бусад хүмүүсийн сурч боловсорч байгааг харах үедээ чи тэднийг үймүүлж, урам хугармаар зүйл хэлдэг. Чи зориг зүрхтэй юм! Чи: “Моабын үр удам ямар боловсролтой байж чадах юм бэ? Би сурахгүй” гэж хэлдэг. Энэ нь араатны хэлэх зүйл биш гэж үү? Чамайг бүр хүн гэж тооцно гэж үү? Би маш ихийг хэлсэн боловч чамд энэ нь нэмэр болсонгүй. Би энэ бүх ажлыг хий дэмий хийсэн гэж үү? Би энэ бүх үгийг хий дэмий хэлсэн гэж үү? Нохой хүртэл сүүлээ шарвах байсан; ийм хүн бүр нохойн чинээнд ч хүрэхгүй! Чамайг хүн гэж дуудахад зохистой гэж үү? Намайг Моабын үр удмын тухай яригуут зарим хүн зориуд өөрсдийгөө дордуулдаг. Тэд өмнөхөөсөө өөрөөр хувцаслан, ихэд сэгсийж арзайчхаад хүн шиг харагддаггүй бөгөөд “Би бол Моабын үр удам. Би сайн биш. Ямар нэгэн ерөөл хүртэнэ гэж бодох нь мөрөөдөж байгаа хэрэг. Моабын үр удам төгс болгуулж чадна гэж үү?” хэмээн бувтнадаг. Намайг Моабын үр удмын тухай яримагц ихэнх хүмүүс итгэл найдвараа алдаж: “Бурхан биднийг Моабын үр удам гэдэг—тэр нь юуг илтгэдэг вэ? Түүний дуу хоолойн өнгөнөөс харвал энэ нь эргэлт буцалтгүй! Түүний үгэнд ямар ч хайр алга. Бид сүйрлийн бай биш гэж үү?” хэмээн хэлдэг. Өмнө нь юу гэж хэлснийг та нар мартчихсан уу? “Моабын үр удам” хэмээх нэр томьёог л одоо чи санаж байгаа юм гэж үү? Үнэндээ олон үг үр дүнд хүрэхийн төлөө байсан боловч тэдгээр нь бас бодит үнэнийг илчилдэг. Ихэнх хүмүүс үүнд итгэдэггүй. Чи Миний төлөө тэгж зовохыг хүсдэггүй. Чи үхлээс айдаг бөгөөд үргэлж зугтахыг хүсдэг. Хэрвээ чи явмаар байвал Би чамайг үлд гэж албадахгүй боловч үүнийг чамд тодорхой хэлэх ёстой: Нэг насныхаа амьдралыг дэмий бүү өнгөрөө, мөн өнгөрсөн үед Миний чамд хэлсэн зүйлсийг бүү март. Бүтээгдсэн зүйлийн хувиар чи бүтээгдсэн зүйлийн үүргийг биелүүлэх ёстой. Мөс чанартаа харшлах зүйлсийг бүү хий; чи бүтээлийн Эзэний төлөө л өөрийгөө зориулах ёстой. Моабын үр удам ч бас бүтээгдсэн зүйл, зүгээр л тэд товойлгогчид бөгөөд хараагдсан юм. Ямар ч байсан чи бүтээгдсэн зүйл хэвээр. Хэрвээ чи ингэж хэлбэл тийм ч хол зөрөхгүй: “Хэдий би Моабын үр удам боловч Бурханы маш их нигүүлслийг эдэлсэн тул мөс чанартай байх ёстой. Би үүнийг зүгээр л хүлээн зөвшөөрнө, гэхдээ үргэлж бодоод байхгүй. Би энэ урсгал дотор зовлоо ч гэсэн эцсийг нь хүртэл зовно. Би Моабын үр удам юм бол тийм л байг. Би эцсийг нь хүртэл дагасаар байна!” Чи эцсийг нь хүртэл дагах ёстой. Хэрвээ чи зугтаавал үнэхээр ямар ч хэтийн ирээдүйгүй байх бөгөөд сүйрлийн замд орчихсон байх болно.

Та нарт гарал үүслийг чинь ойлгуулах нь сайн хэрэг бөгөөд та нарт бодит үнэнийг ойлгуулах нь ажилд ач тустай юм. Ингэхгүй бол хүссэн үр дүндээ хүрч

чадахгүй. Энэ нь байлдан дагуулалтын ажлын нэг хэсэг бөгөөд ажлын зайлшгүй алхам билээ. Тэр бол бодит баримт. Энэ ажлыг хийх нь хүмүүсийн сүнсийг сэрээж, мөс чанарын мэдрэмжүүдийг сэрээж, хүмүүст энэ агуу авралыг олж авах боломжийг олгох учиртай юм. Хэрвээ хүн мөс чанартай бол өөрсдийгөө дорд байр сууринд байгааг харах үедээ Бурханд бүр ч их талархах ёстой. Тэд Түүний үгийг гартаа барьж, Түүний өгсөн нигүүлслээс ягштал зуурч, бүр гашуунаар уйлан, ингэж хэлэх ёстой: “Бидний байр суурь дорд бөгөөд бид энэ дэлхий ертөнцөөс юу ч олж аваагүй. Дорд хүмүүс биднийг хэн ч тоодоггүй. Бид гэр орондоо хавчигддаг, нөхрүүд маань биднийг голж, эхнэрүүд маань биднийг хараараж зүхдэг, хүүхдүүд маань биднийг дорд үздэг ба биднийг хөгшрөх үед бэрүүд маань ч бас биднийг ад үздэг. Бид үнэхээр багагүй зовсон бөгөөд одоо Бурханы агуу хайрыг эдэлж байгаа нь үнэхээр сайн зол завшаан юм! Бурхан биднийг авраагүй бол бид хүмүүний зовлонг тодорхой харж яаж чадах билээ? Бид энэ нүгэлдээ доройтсоор байх бус уу? Энэ нь Бурхан биднийг өргөж байгаа хэрэг биш гэж үү? Би хамгийн дорд хүмүүсийн нэг бөгөөд Бурхан намайг маш өндөрт өргөсөн. Би сүйрсэн ч гэсэн Түүний хайрыг хариулах учиртай. Бурхан биднийг өндрөөр бодож, ийм дорд хүмүүс бидэнтэй нүүр тулан ярилцдаг. Надад зааж сургахын тулд Тэр гараас минь хөтөлдөг. Тэр намайг амаараа хооллодог. Надтай хамт амьдарч, хамт зовдог. Тэр намайг гэсгээсэн ч гэсэн—би юу хэлж чадах юм бэ? Гэсгээгдэх нь ч бас Бурханаар өргүүлж байгаа хэрэг бус уу? Гэсгээгддэг ч гэсэн би Түүний зөвт байдлыг харж чадна. Би мөс чанаргүй байж болохгүй—Бурханы хайрыг хариулах ёстой. Би Бурханы эсрэг дахин тэрсэлж болохгүй.” Бурханы байр суурь, ялгамж чанар хүмүүсийнхтэй адилгүй—Түүний зовлон адилхан, Түүний иддэг, өмсдөг зүйл адилхан боловч бүх хүн Түүнийг хүндэлдэг, энэ л цорын ганц ялгаа юм. Түүний эдэлдэг бусад бүх зүйл хүнтэй адилхан биш гэж үү? Тэгвэл, та нар тодорхой нэг байдлаар чамд хандахыг Бурханаас шаардах ямар эрхтэй юм бэ? Бурхан ийм их зовлон туулж, ийм агуу ажил хийсэн ба шоргоолжноос дор, шавжнаас дор та нар өнөөдөр ийм өндөрт өргөгдсөн. Хэрвээ чи Бурханы хайрыг хариулж чадахгүй бол мөс чанар чинь хаана байна вэ? Зарим хүн: “Бурханыг орхин явах тухай бодох болгонд миний нүд нулимсаар дүүрч, мөс чанар маань буруутгадаг. Би Бурханд өртэй. Би үүнийг хийж чадахгүй. Түүнд ингэж хандаж чадахгүй. Хэрвээ би үхээд, тэгснээрээ Түүний ажилд алдрыг өгөх байсан бол би тун сэтгэл хангалуун байх байсан. Эс бөгөөс амьдарч байсан ч гэсэн би санаа амар байж чадахгүй” хэмээн үнэн сэтгэлээсээ хэлдэг. Эдгээр үгийг сонс—энэ нь бүтээгдсэн зүйлийн биелүүлэх ёстой үүргийг дүрсэлдэг. Хэрвээ хүнд ийм үзэгдэл үргэлж байдаг бол дотроо тодорхой, санаа амар байх болно; тэд эдгээр хэрэг явдлын талаар тодорхой мэдэж байх болно. Чи: “Бурхан намайг хорлоогүй, бас зориуд надаар тоглож, эсвэл намайг доромжлоогүй. Хэдийгээр Тэр бага зэрэг ширүүн ярьж, энэ нь зүрх сэтгэлийг хатгадаг боловч миний төлөө байдаг. Хэдий Тэр маш ширүүн ярьдаг боловч намайг аварсаар байгаа ба миний сул талыг анхаарсаар байгаа. Тэр бодит

баримт ашиглан намайг шийтгэж байгаа юм биш. Бурхан бол аврал гэдэгт би итгэдэг" гэж хэлнэ. Хэрвээ чамд үнэхээр ийм үзэгдэл байх юм бол чи зугтахгүй. Мөс чанар чинь чамайг орхихгүй ба чамайг яллан Бурханд тэгж хандах ёсгүй гэдгийг хэлнэ. Чи өөрийн олж авсан бүх нигүүлслийг бодно. Чи Миний маш олон үгийг сонссон—тэдгээрийг хий дэмий сонссон юм гэж үү? Хэн зугтах нь хамаагүй, чи болохгүй. Бусад хүмүүс итгэхгүй байсан ч чи итгэх ёстой. Бусад хүмүүс Бурханыг орхидог ч чи Бурханыг хамгаалж, Түүнд гэрчлэл хийх ёстой. Бусад нь Бурханыг гүтгэж байсан ч чи болохгүй. Бурхан чамд хэчнээн хахир хатуу хандсан ч бай, чи Түүнд зөв хандах ёстой. Чи Түүний хайрыг хариулах ёстой ба мөс чанартай байх учиртай, учир нь Бурхан гэм зэмгүй. Хүн төрөлхтний дунд ажиллахын тулд тэнгэрээс газар дээр ирснээр Тэр аль хэдийн асар их доромжлол амссан. Тэрээр өчүүхэн төдий ч бузар заваан зүйлгүй ариун билээ. Бузар газарт ирснээр Тэр хэр их доромжлол амссан бэ? Тэр та нарын төлөө та нар дээр ажилладаг. Хэрвээ чи Түүнд мөс чанаргүй ханддаг бол эртхэн үхсэн чинь дээр!

Яг одоо ихэнх хүмүүст үзэгдлийн энэ тал дутагдаж байгаа; тэд энэ ажлыг ер ойлгож чаддаггүй, энэ ажлаар дамжуулан Бурхан юуг эцэст нь гүйцэлдүүлэх гэж байгааг мэддэггүй. Ялангуяа юмны учир ойлгодоггүй тэр хүмүүс, төөрдөг байшинд орчихсон мэт байж, хэдхэн эргэлтийн дараа замаа алддаг. Хэрвээ чи тэдэнд Бурханы удирдлагын төлөвлөгөөний зорилгыг нэгд нэггүй тайлбарлавал тэд будилахгүй. Олон хүн үүнийг ойлгож чаддаггүй ба Бурханы ажил нь хүмүүсийг тамлахын төлөө байдаг гэж итгэдэг. Тэд Түүний ажлын мэргэн ухаан болон гайхалтай байдлыг ойлгодоггүй ба Түүний ажил Түүний хүч чадлыг илчлэхийн төлөө, үүнээс ч илүүтэйгээр хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг гэдгийг ойлгодоггүй. Тэд тэр бүхнийг хардаггүй; зүгээр л өөрсдөд нь ямар нэгэн хэтийн ирээдүй байгаа эсэхийг болон тэнгэрт орж чадах эсэхээ хардаг. Тэд: "Бурханы ажил дандаа маш тойруу байдаг; энэ нь бидэнд Таны мэргэн ухааныг шууд харуулдаггүй. Та биднийг ийм байдлаар тамлах ёсгүй. Бидний хэв чанар хэтэрхий дутмаг бөгөөд бид Таны хүслийг ойлгодоггүй. Та зүгээр л шууд хэлж, хийдэг бол сайн байх сан. Та биднээр таамаглуулахыг хүсдэг боловч бид чадахгүй. Хэрвээ Та яаравчлан, Өөрийн алдрыг бидэнд харуулбал сайн байна. Юмыг ийм тойруу замаар хийх нь ямар хэрэгтэй юм бэ?" гэж хэлдэг. Та нарт одоо хамгийн их дутагдаж байгаа зүйл бол мөс чанар. Илүү их мөс чанартай бай. Энэ ажлын алхмуудыг үнэндээ хэн хийж байгааг харахын тулд нүдээ сайн нээ. Бүү яаран дүгнэлт гарга. Одоо чи сайндаа л, өөрийн туулах ёстой амийн замын өнгөц талыг ойлгосон. Чиний туулах ёстой үнэн асар их байсаар байгаа бөгөөд үүнийг бүрэн ойлгож чадах өдөр ирэхэд чи ийм маягаар ярихаа болино, гомдоллохоо ч болино. Мөн юмыг хөнгөхнөөр тодорхойлохгүй. "Бурхан маш ухаалаг, Бурхан маш ариун, Бурхан маш хүчирхэг!" гэж чи хэлнэ.

ПЕТРИЙН ТУРШЛАГА: ГЭСГЭЭЛТ, ШҮҮЛТИЙН ТАЛААРХ ТҮҮНИЙ МЭДЛЭГ

Бурханаар гэсгээгдэж байх үедээ Петр: “Өө Бурхан минь! Миний махан бие дуулгаваргүй бөгөөд Та намайг гэсгээж, намайг шүүдэг. Би Таны гэсгээлт, шүүлтэд баярлан хөөрдөг ба Та намайг хүсэхгүй байсан ч гэсэн Таны шүүлтээс би ариун, зөвт зан чанарыг тань хардаг. Намайг шүүх үед тань бусад хүмүүс Таны шүүлтээс Таны зөвт зан чанарыг харж болох учраас би сэтгэл хангалуун байдаг. Хэрвээ энэ нь Таны зан чанарыг илэрхийлж, бүх бүтээлд Таны зөвт зан чанарыг харуулах юм бол, мөн Таныг гэх хайр минь илүү цэвэр болж, би зөв шударга нэгний төрхтэй болж чадах юм бол Таны шүүлт сайн, учир нь Таны нигүүлсэнгүй хүсэл энэ билээ. Миний дотор одоо ч тэрслүү зүйл их байгаа ба Таны өмнө очиход тохирохгүй хэвээр гэдгээ би мэднэ. Хатуу ширүүн орчноор ч бай, эсвэл асар их зовлонгоор дамжуулаад ч бай, Та намайг бүр их шүүгээсэй гэж би хүсэж байна; Та юу ч хийсэн бай, миний хувьд энэ нь үнэ цэнтэй. Таны хайр маш гүн гүнзгий бөгөөд би өчүүхэн төдий ч гомдолгүйгээр Таны зохицуулалтад өөрийгөө өгөхөд бэлэн байна” гэж залбирсан. Энэ бол Бурханы ажлыг туулсны дараах Петрийн мэдлэг, мөн Бурханыг гэсэн түүний хайрын гэрчлэл юм. Өнөөдөр та нар аль хэдийн байлдан дагуулагдсан—гэхдээ энэхүү байлдан дагуулалтыг та нар хэрхэн илэрхийлдэг вэ? Зарим хүн: “Байлдан дагуулагдсан минь Бурханы эрхэм дээд нигүүлсэл, өргөмжлөл юм. Хүний амьдрал хоосон бөгөөд ямар ч утга учиргүй. Хүн яаран тэвдэж амьдралаа өнгөрүүлэн, үеэс үед үр хүүхэд төрүүлж, өсгөдөг ба эцэстээ юу ч үгүй хоцордог. Өнөөдөр, Бурханаар байлдан дагуулагдсаныхаа дараа л би ингэж амьдрах нь ямар ч үнэ цэнгүйг харлаа; энэ үнэхээр утга учиргүй амьдрал юм. Би ер нь үхээд, энэ бүхнийг дуусгасан нь дээр юм байна!” гэж хэлдэг. Байлдан дагуулагдсан тийм хүмүүс Бурханаар авхуулж чадах уу? Тэд үлгэр жишээ, үлгэр дуурайл болж чадах уу? Тийм хүмүүс бол идэвхгүй байдлын сурах бичиг юм; тэдэнд ямар ч хүсэл тэмүүлэл байдаггүй, өөрсдийгөө сайжруулахаар чармайдаггүй. Хэдий тэд байлдан дагуулагдсан гэж тооцогддог ч тийм идэвхгүй хүмүүс төгс болгуулж чадахгүй. Амьдралынхаа бараг төгсгөлд, төгс болгуулсныхаа дараа Петр: “Өө Бурхан минь! Хэрвээ би дахиад хэдхэн жил амьдарсан бол Таныг гэх хайраа илүү ариун, илүү гүнзгий болгохыг хүсэх байсан” гэж хэлсэн юм. Загалмайд бараг цовдлогдох гэж байх үедээ тэр зүрх сэтгэлдээ ийнхүү залбирчээ: “Өө Бурхан минь! Таны цаг одоо ирлээ; надад зориулж Таны бэлтгэсэн цаг ирлээ. Би Таны төлөө цовдлогдох ёстой, Танд энэ гэрчлэлийг хийх ёстой ба миний хайр Таны шаардлагыг хангаж, илүү ариун болж чадна гэж би найдаж байна. Өнөөдөр Таны төлөө үхэж, цовдлогдож чадаж байгаа нь намайг тайвшруулж, санаа амрааж байна, учир нь миний хувьд Таны төлөө цовдлогдож, Таны хүслийг хангалуун байлгаж, Танд өөрийгөө өгч чаддаг байж, Танд амиа өргөн барихаас илүү таатай зүйл юу ч үгүй билээ. Өө Бурхан минь! Та үнэхээр хайр татам! Хэрвээ Та намайг

амьдруулсан бол би Таныг хайрлахад бүр ч бэлэн байх байлаа. Амьд байгаа цагтаа би Таныг хайрлана. Би Таныг илүү гүн гүнзгий хайрлахыг хүсэж байна. Би зөв шударга биш, нүгэлтэй учраас Та намайг шүүж, намайг гэсгээж, намайг шалгадаг. Тэгээд Таны зөвт зан чанар надад бүр ч илэрхий болдог. Энэ нь миний хувьд ерөөл юм, учир нь би Таныг илүү гүн гүнзгий хайрлаж чадах ба Та намайг хайрлахгүй байсан ч гэсэн би Таныг ийм маягаар хайрлахад бэлэн байна. Энэ нь намайг илүү утга учиртай амьдралыг амьдран харуулах чадвартай болгодог учраас Таны зөвт зан чанарыг харахад би бэлэн байна. Миний амьдрал одоо илүү утга учиртай болсон мэт надад санагдаж байна, учир нь би Таны төлөө цовдлогдож байгаа ба Таны төлөө үхэх нь утга учиртай билээ. Гэсэн ч, би Таныг хэтэрхий бага мэддэг учраас, Таны хүслийг бүрэн хангалуун болгож чадахгүйгээ мэддэг учраас, мөн Таны ачийг хэтэрхий бага хариулсан учраас одоо ч сэтгэл ханахгүй байна. Амьдралдаа би, өөрийгөө Танд бүхэлд нь буцаан өгч чадаагүй; би мөн ч хол байна даа. Энэ мөчид эргээд бодоход би Танд маш их өртэйгөө мэдэрч байгаа бөгөөд бүх алдаагаа болон Танд буцаан өгч чадаагүй бүх хайраа эргүүлэн төлөхөд энэ мөчийг л ашиглаж чадна.”

Хүн утга учиртай амьдралыг амьдран харуулахаар зорих ёстой ба одоогийн нөхцөл байдалдаа сэтгэл ханах ёсгүй. Петрийн дүр төрхийг амьдран харуулахын тулд хүн Петрийн мэдлэг, туршлагыг эзэмших ёстой. Хүн илүү өндөр дээд, илүү гүн гүнзгий зүйлсийг эрэлхийлэх ёстой. Бурханыг гэх илүү гүн гүнзгий, илүү ариун хайрыг, мөн үнэ цэнтэй, утга учиртай амьдралыг эрэлхийлэх ёстой. Зөвхөн энэ л амьдрал юм; энэ үед л хүн Петртэй адил байх болно. Чи эерэг талд идэвхтэйгээр орох идэвх санаачилга гаргахад төвлөрөх ёстой ба илүү гүн гүнзгий, илүү нарийн ширийн, илүү бодитой үнэнийг үл хайхран орхих зуураа түрхэн зуурын амар тайвны төлөө ухарч няцахыг өөртөө дуулгавартайяа зөвшөөрөх ёсгүй. Чиний хайр бодит байх ёстой ба чи энэхүү доройтож гажуудсан, зовох юмгүй, амьтныхаас өөрцгүй амьдралаас өөрийгөө чөлөөлөх арга замыг олох ёстой. Чи утга учиртай, үнэ цэнтэй амьдралыг амьдран харуулах ёстой бөгөөд өөрийгөө хуурч, амьдралаа тоглоом шиг үзэх ёсгүй. Бурханыг хайрлахаар хүсэн тэмүүлдэг хүн бүрийн хувьд олж авч чадашгүй үнэн гэж үгүй бөгөөд бат зогсож чадахааргүй шударга ёс гэж үгүй билээ. Чи хэрхэн амьдрах ёстой вэ? Чи Бурханыг хэрхэн хайрлаж, Түүний хүслийг биелүүлэхийн тулд энэхүү хайраа хэрхэн ашиглах ёстой вэ? Чиний амьдралд үүнээс илүү том зүйл байхгүй. Юун түрүүнд, чи тийм хүсэл тэмүүлэл, цөхрөлтгүй оролдлоготой байх ёстой ба ноён нуруугүй, сул дорой амьтад шиг байх ёсгүй. Чи утга учиртай амьдралыг, утга учиртай үнэнийг хэрхэн туулахыг сурах ёстой бөгөөд тийм маягаар өөртөө хааш яаш хандах ёсгүй. Нэг л мэдэхэд амьдрал чинь урсаад өнгөрнө; үүний дараа чамд Бурханыг хайрлах өөр боломж олдох уу? Үхсэнийхээ дараа хүн Бурханыг хайрлаж чадах уу? Чи Петр шиг хүсэл тэмүүлэлтэй, мөс чанартай байх ёстой; амьдрал чинь утга учиртай байх ёстой, мөн чи өөрөөрөө тоглох ёсгүй. Хүний хувиар, Бурханыг эрэлхийлдэг хүний хувиар чи амьдралдаа

хэрхэн хандахаа, өөрийгөө Бурханд хэрхэн өргөл болгох ёстойгоо, Бурханд итгэх итгэлээ хэрхэн илүү утга учиртай байлгах ёстойгоо болон нэгэнт Бурханыг хайрладаг тул яаж илүү ариун, илүү сайхан, илүү сайн байдлаар Түүнийг хайрлах ёстойгоо анхааралтай бодолцон үзэж чаддаг байх ёстой. Өнөөдөр чи байлдан дагуулагдсандаа сэтгэл хангалуун байгаад зогсохгүй, ирээдүйд алхах замаа ч бас бодолцон үзэх ёстой. Чи төгс болгуулах хүсэл тэмүүлэл, зориг зүрхтэй байх ёстой ба өөрийгөө чадваргүй гэж дандаа бодох ёсгүй. Үнэн хүнийг алагчилж үздэг үү? Үнэн хүмүүсийг албаар эсэргүүцэж чадах уу? Хэрвээ чи үнэнийг эрэлхийлбэл энэ нь чамайг цөхрүүлж чадах уу? Хэрвээ чи шударга ёсны төлөө бат зогсвол энэ нь чамайг түлхэн унагаах уу? Хэрвээ чи үнэхээр амийг эрэлхийлэхээр эрмэлздэгбол амь чамаас зугтаж чадах уу? Хэрвээ чамд үнэн байхгүй бол энэ нь, үнэн чамайг үл тоодгоос болдог юм биш, харин чи үнэнээс хол хөндий байдгаас болдог; хэрвээ чи шударга ёсны төлөө бат зогсож чаддаггүй бол шударга ёсонд ямар нэг буруу зүйл байгаа юм биш, харин чи шударга ёс бодит баримттай нийцдэггүй гэж үздэгээс болдог; хэрвээ чи олон жил эрж хайсан ч амийг олж аваагүй бол амь чамд мөс чанаргүй хандаж байгаа юм биш, харин чамд амийг гэх мөс чанар байхгүй бөгөөд амийг хөөн зайлуулснаас болдог; хэрвээ чи гэрэлд амьдардаг ч гэрлийг олж авах чадваргүй байсаар ирсэн бол гэрэл чамайг гэрэлтүүлж чаддаггүйгээс энэ нь болсон юм биш, харин чи гэрлийн оршин тогтнолд ямар ч анхаарал хандуулаагүй болохоор гэрэл чамаас чимээгүй холдон одсоноос болдог. Хэрвээ чи эрэлхийлдэггүй бол чамайг, амьдралдаа ямар ч зориг зүрхгүй, харанхуйн хүчийг эсэргүүцэн сөрөх сэтгэлгүй, үнэ цэнгүй хог шаар гэж л хэлж болно. Чи хэтэрхий сул дорой! Чи өөрийг чинь хүрээлэн байгаа Сатаны хүчнээс зугтах чадваргүй ба ийм аюулгүй, амар тайван амьдралаар амьдарч, мэдлэггүй хэвээр үхэхийг л хүсдэг. Чиний биелүүлэх ёстой зүйл бол байлдан дагуулагдах эрэл хайгуул; энэ бол чиний хүлээсэн үүрэг. Хэрвээ чи байлдан дагуулагдахдаа л сэтгэл ханадаг бол гэрлийн оршин тогтнолыг хөөн зайлуулж байгаа хэрэг юм. Чи үнэний төлөө зовлон зүдүүр туулах ёстой, үнэний төлөө өөрийгөө зориулах ёстой, үнэний төлөө доромжлол амсах ёстой, илүү их үнэнийг олж авахын тулд илүү их зовлон амсах ёстой. Энэ нь чиний хийх ёстой зүйл юм. Амар амгалан гэр бүлийн амьдралын төлөө чи үнэнийг хаях ёсгүй ба түр зуурын таашаалын төлөө өөрийн амьдралын нэр хүнд, ёс жудгийг алдах ёсгүй. Чи сайн сайхан, үзэсгэлэнтэй бүхнийг эрэлхийлж, илүү утга учиртай амьдралын замыг эрэлхийлэх ёстой. Хэрвээ чи энгийн дорд амьдралаар амьдардаг ба ямар ч зорилгыг эрэлхийлдэггүй бол амьдралаа дэмий үрж байгаа хэрэг биш гэж үү? Чи тийм амьдралаас юу олж авч чадах юм бэ? Чи нэг үнэний төлөө бие махбодын бүх таашаалыг орхих ёстой ба багахан таашаалын төлөө бүх үнэнийг хаях ёсгүй. Иймэрхүү хүмүүст ямар ч ёс жудаг, нэр хүнд байдаггүй; тэдний оршин тогтнолд ямар ч утга учир байдаггүй!

Өөрийнхөө ажлын шаардлагаар, түүнчлэн хүнд хэрэгтэй учраас Бурхан хүнийг гэсгээж, шүүдэг. Хүн гэсгээгдэж, шүүгдэх хэрэгтэй ба ингэснээр л Бурханыг гэх

хайранд хүрч чадна. Өнөөдөр, та нар бүрэн үнэмшсэн боловч өчүүхэн төдий бүтэлгүйтэл тулгарахад асуудалд ордог; биеийн хэмжээ чинь хэтэрхий жаахан хэвээр бөгөөд илүү гүн гүнзгий мэдлэгт хүрэхийн тулд тийм гэсгээлт, шүүлтийг илүү их туулах хэрэгтэй. Өнөөдөр та нар Бурханд зарим нэг талаар хүндэтгэлтэй ханддаг, Бурханаас эмээдэг ба Тэр бол жинхэнэ Бурхан гэдгийг мэддэг ч цэвэр ариун хайранд хүрэх нь байтугай, Түүнийг гэх тийм их хайр ч та нарт байдаггүй; мэдлэг чинь хэтэрхий өнгөц, биеийн хэмжээ чинь мөн л хангалтгүй. Хүрээлэн байгаа орчинтой үнэхээр тулгарах үедээ та нар мөн л гэрчлэл хийгээгүй, оролтын чинь дэндүү багахан нь санаачилгатай байдаг ба хэрхэн хэрэгжүүлэхээ огт мэддэггүй. Ихэнх хүмүүс идэвхгүй, үлбэгэр байдаг; тэд зөвхөн Бурханыг зүрх сэтгэлдээ нууцхан хайрладаг, гэхдээ тэдэнд хэрэгжүүлэх арга зам байдаггүй, өөрсдийнх нь зорилго юу болохыг ч тодорхой мэддэггүй. Төгс болгуулсан хүмүүс хэвийн хүн чанартай байдгаар үл барам, мөс чанарын хэмжүүрээс даван гарсан, мөс чанарын стандартаас илүү өндөр дээд үнэнийг эзэмшдэг; тэд Бурханы хайрыг хариулахад мөс чанараа ашигладгаар үл барам, үүнээс ч илүүтэйгээр Бурханыг мэдсэн ба Бурхан бол хайр татам, хүний хайрыг хүртүүштэй гэдгийг, мөн хайрлуулах зүйл Бурханд маш их байдаг болохоор хүн өөрийн эрхгүй Бурханыг хайрладаг гэдгийг харсан! Төгс болгуулсан хүмүүсийн Бурханыг гэх хайр нь хувийн хүсэл тэмүүллээ биелүүлэхийн төлөө байдаг. Тэдний хайр бол аяндаа гардаг хайр, эргүүлээд юу ч нэхдэггүй хайр бөгөөд арилжаа наймаа биш. Тэд Бурханыг мэддэгээсээ болоод л Түүнийг хайрладаг. Тийм хүмүүс Бурхан өөрсдөд нь нигүүлсэл хайрлах эсэхийг анхаардаггүй ба Бурханыг хангалуун байлгах төдийд л сэтгэл ханадаг. Тэд Бурхантай наймаа хийдэггүй, мөн “Та надад өгсөн, тиймээс хариуд нь би Таныг хайрлана; хэрвээ Та надад өгөхгүй бол би ч гэсэн хариуд нь Танд юу ч өгөхгүй” гэх мөс чанараар Бурханыг гэх хайраа хэмждэггүй. Төгс болгуулсан хүмүүс: “Бурхан бол Бүтээгч бөгөөд бидэн дээр Өөрийн ажлыг гүйцэтгэдэг. Төгс болгуулах энэ боломж, нөхцөл, эрх надад байгаа тул би утга учиртай амьдралыг амьдран харуулахаар эрэлхийлж, Түүнийг хангалуун болгох ёстой” гэж үргэлж боддог. Петрийн мэдэрсэн зүйлтэй энэ нь яг адилхан: Тэр хамгийн сул дорой байх үедээ Бурханд залбирч, “Өө Бурхан минь! Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран би Таныг үргэлж санадаг гэдгийг Та мэднэ. Цаг хугацаа, орон зай ямар ч байсан, би Таныг хайрлахыг хүсдэгийг Та мэднэ, гэхдээ миний биеийн хэмжээ хэтэрхий жаахан, би дэндүү сул дорой, хүчин мөхөс, миний хайр хэтэрхий хязгаарлагдмал, Танд хандах чин сэтгэл минь дэндүү хомс билээ. Таны хайртай харьцуулбал би зүгээр л амьдрахад ч тохирохгүй. Миний амьдрал хий дэмий биш байж, Таны хайрын ачийг хариулаад зогсохгүй, түүнчлэн өөрт байгаа бүхнээ Танд зориулахыг л би хүсдэг. Хэрвээ би Таныг хангалуун болгож чадвал бүтээлийн хувиар сэтгэлийн амар амгаланг олж авах ба үүнээс өөр юуг ч би хүсэхгүй. Хэдийгээр би одоо сул дорой, хүч чадалгүй байгаа ч Таны ятгалгыг мартахгүй, Таны хайрыг мартахгүй. Одоо би зөвхөн Таны хайрыг хариулахаас

хэтрэхгүй байна. Өө Бурхан минь, надад таагүй санагдаж байна! Өөрийн зүрх сэтгэл дэх хайрыг би Танд хэрхэн буцаан өгөх вэ, би яаж чадах бүхнээ хийж, Таны хүслийг биелүүлж чаддаг байж, өөртөө байгаа бүхнийг Танд өргөн барьж чадах билээ? Та хүний сул талыг мэднэ; би яаж Таны хайрыг хүртэхүйц байж чадах юм бэ? Өө Бурхан минь! Миний биеийн хэмжээ жаахан гэдгийг, миний хайр хэтэрхий хомс гэдгийг Та мэднэ. Ийм орчинд би яаж чадах бүхнээ хийх вэ? Таны хайрыг хариулах ёстойгоо би мэднэ, өөртөө байгаа бүхнийг Танд өгөх ёстойгоо би мэднэ, гэвч өнөөдөр миний биеийн хэмжээ хэтэрхий жаахан байна. Надад хүч чадал, итгэл өгөхийг би Танаас гуйж байна, ингэснээр би Танд зориулах илүү цэвэр ариун хайрыг эзэмшиж чаддаг болж, өөртөө байгаа бүхнийг Танд зориулж чаддаг болно; би Таны хайрыг хариулах чадвартай байгаад зогсохгүй, Таны гэсгээлт, шүүлт, шалгалт болон илүү хүчтэй хараалыг ч гэсэн туулж чадна. Та надад Өөрийн хайрыг харуулсан ба Таныг хайрлахгүй байж би чадахгүй, хэдий би өнөөдөр сул дорой, хүчин мөхөс байгаа ч Таныг мартаж яахан чадах билээ? Таны хайр, гэсгээлт, шүүлт бүгд Таныг надад мэдүүлсэн ч Та маш агуу учраас Таны хайрыг хангах чадваргүйгээ би бас мэдэрдэг. Би өөртөө байгаа бүхнийг хэрхэн Бүтээгчид зориулж чадах билээ?" гэж хэлсэн. Петрийн хүсэлт ийм байсан ч биеийн хэмжээ нь хэтэрхий хангалтгүй байлаа. Энэ мөчид зүрхэнд нь хутга зоогоод эргүүлж байгаа мэт түүнд санагджээ. Тэрээр шаналан тарчилж байлаа; тийм нөхцөл байдалд тэр юу хийхээ мэдэхгүй байв. Гэсэн ч тэр ийнхүү үргэлжлүүлэн залбирсан юм: "Өө Бурхан минь! Хүний биеийн хэмжээ балчир бага, мөс чанар нь сул дорой ба миний хийж чадах цорын ганц зүйл бол Таны хайрыг хариулах билээ. Өнөөдөр би Таны хүслийг хэрхэн хангахаа мэддэггүй бөгөөд чадах бүхнээ хийж, байгаа бүхнээ өгч, өөрт байгаа бүхнийг Танд зориулахыг л хүсдэг. Таны шүүлтээс үл хамааран, Таны гэсгээлтээс үл хамааран, Та надад юу өгөхөөс үл хамааран, Та надаас юу авахаас үл хамааран, Танд хандах өчүүхэн төдий гомдлоос ч намайг чөлөөлж өгөөч. Олон удаа, Та намайг гэсгээж, шүүх үед би дотроо гомдоллон, ариун байдалд хүрэх юм уу Таны хүслийг биелүүлэх чадваргүй байсан. Таны хайрыг хариулсан минь аргагүй байдалд орсноос болсон ба энэ мөчид би өөрийгөө бүр ч их үзэн ядаж байна." Бурханыг гэх илүү цэвэр ариун хайрыг эрж хайсан учраас Петр ийнхүү залбирсан юм. Тэрээр эрж хайж, гуйж байсан, түүнчлэн өөрийгөө буруутгаж, өөрийн нүглийг Бурханд улайж байлаа. Тэрээр Бурханд өртэйгөө мэдэрч, өөрийгөө үзэн ядсан мөртөө бас бага зэрэг гунигтай, идэвхгүй байв. Бурханы хүслийн төлөө хангалттай сайн байж чадахгүй байгаа мэт, чадлаараа хичээж чадахгүй байгаа мэт түүнд дандаа санагддаг байжээ. Тийм нөхцөл байдалд Петр Иовын итгэлийг эрэлхийлсээр байсан. Иовын итгэл хэчнээн их байсныг тэр харсан, учир нь өөрийнх нь бүх зүйл Бурханаас өгөгдсөн, Бурхан өөрөөс нь бүх юмыг эргүүлэн авах нь зүйн хэрэг бөгөөд Бурхан Өөрийн хүссэнээр хэнд ч өгч болно—энэ бол Бурханы зөвт зан чанар гэдгийг Иов харсан юм. Иовд ямар ч гомдол байгаагүй, Бурханыг магтсаар байж чадсан. Петр ч бас өөрийгөө мэдэж байсан ба зүрх сэтгэлдээ ийнхүү

залбирсан: “Өнөөдөр би, мөс чанараа ашиглан Таны хайрыг хариулж байгаадаа, мөн хэчнээн их хайрыг Танд буцааж өгсөндөө сэтгэл ханах ёсгүй, учир нь миний бодол санаа хэтэрхий завхарсан бөгөөд би Таныг Бүтээгч хэмээн харж чаддаггүй билээ. Би одоо ч гэсэн Таныг хайрлахад тохирохгүй учраас өөртөө байгаа бүхнийг Танд зориулж чаддаг болох ёстой ба үүнийг би дуртайяа хийх болно. Би Таны хийсэн бүхнийг мэдэж, сонголтгүй байх ёстой ба Таны хайрыг харж, Таныг магтан, Таны ариун нэрийг дээдлэн магтаж чаддаг байх ёстой, ингэснээр Та надаар дамжуулан агуу алдар сууг олж авч болох юм. Би Таныг гэх энэ гэрчлэлдээ бат зогсоход бэлэн байна. Өө Бурхан минь! Таны хайр маш эрхэм нандин, гайхалтай сайхан; би муу ёрын нэгний гарт амьдрахыг хүсэж яахан чадах билээ? Намайг Та бүтээсэн бус уу? Би яаж Сатаны эзэмшил дор амьдарч чадах юм бэ? Би бүхий л оршихуй минь Таны гэсгээлт дунд амьдрахыг илүүд үзнэ. Би муу ёрын нэгний эзэмшил дор амьдрахыг хүсэхгүй байна. Хэрвээ би ариусгагдаж, өөрт байгаа бүхнээ Таны төлөө зориулж чадах л юм бол өөрийн бие болон оюун санааг Таны шүүлт, гэсгээлтэд өргөн барихад бэлэн байна, учир нь би Сатаныг жигшдэг ба түүний эзэмшил дор амьдрахыг хүсдэггүй. Намайг шүүснээрээ Та Өөрийн зөвт зан чанарыг харуулдаг; би аз жаргалтай, өчүүхэн төдий ч гомдолгүй байна. Бүтээлийн үүргээ биелүүлж чадаж л байвал миний бүх амьдралыг Таны шүүлт дагалдахад би бэлэн байна, үүгээр дамжуулан би Таны зөвт зан чанарыг мэдэж авч, муу ёрын нэгний нөлөөнөөс өөрийгөө ангижруулна.” Петр үргэлж ингэж залбирсан, үргэлж ингэж эрж хайсан ба харьцангуй өндөр түвшинд хүрсэн. Тэрээр Бурханы хайрыг буцаан төлж чадаад зогсохгүй, хамгийн чухал нь бүтээлийн үүргээ ч бас биелүүлсэн юм. Тэр мөс чанартаа зэмлүүлээгүйгээр үл барам, мөс чанарын стандартыг даван гарч чадсан юм. Түүний залбирал Бурханы өмнө очсоор байсан болохоор түүний хүсэл тэмүүлэл улам өндөр болж, Бурханыг гэх хайр нь бүр ч их болсон. Хэдий тэр зовлонт шаналлыг туулсан ч Бурханыг хайрлахаа мартаагүй ба Бурханы хүслийг ойлгох чадвартай болохоор эрж хайсаар байсан юм. Залбиралдаа тэр дараах үгсийг хэлсэн: “Би Таны хайрыг хариулахаас хэтрээгүй. Би Сатаны өмнө Танд гэрчлэл хийгээгүй, Сатаны нөлөөнөөс өөрийгөө чөлөөлж чадаагүй ба махан бие дотор амьдарсаар л байна. Би Сатаныг ялж, түүнийг шившиглэхийн тулд өөрийн хайрыг ашиглаж, улмаар Таны хүслийг хангахыг хүсэж байна. Би өөрийнхөө өчүүхэн хэсгийг ч Сатанд өгөлгүйгээр, өөрийгөө бүхэлд нь Танд өгөхийг хүсэж байна, учир нь Сатан бол Таны дайсан билээ.” Ийнхүү эрж хайх тусам, түүний сэтгэл улам хөдөлж, эдгээр зүйлийн талаарх түүний мэдлэг улам ихэссэн. Нэг л мэдэхэд тэрээр Сатаны нөлөөнөөс өөрийгөө чөлөөлж, Бурханд өөрийгөө бүрмөсөн буцаан аваачих ёстой гэдгийг мэдэж авсан юм. Энэ нь түүний хүрсэн түвшин байлаа. Тэр Сатаны нөлөөг даван гарч, махан биеийн зугаа цэнгэл, таашаалаас ангижирч байсан ба Бурханы гэсгээлт, шүүлтийн аль алийг илүү гүн гүнзгий мэдрэхэд бэлэн байв. Тэрээр: “Би Таны гэсгээлт дунд, Таны шүүлт дунд амьдардаг хэдий ч, хэчнээн их зовсон ч гэсэн Сатаны эзэмшил дор амьдрахыг

хүсэхгүй л байна, Сатаны ов мэхэнд автахыг ч хүсэхгүй л байна. Би Таны хараал дунд амьдрахдаа баярлаж, Сатаны ерөөл дунд амьдрахдаа шаналдаг. Таны шүүлтийн дунд амьдарснаар би Таныг хайрладаг, энэ нь надад асар их баяр хөөр авчирдаг. Таны гэсгээлт, шүүлт зөвт агаад ариун; энэ нь намайг цэвэрлэхийн төлөө, үүнээс ч илүүтэйгээр намайг аврахын төлөө байдаг. Би Таны халамжинд байхын тулд бүх амьдралаа Таны шүүлтийн дунд өнгөрөөхийг илүүд үзнэ. Би Сатаны эзэмшил дор ганц ч хором амьдрахыг хүсэхгүй; би Танаар цэвэрлүүлэхийг хүсдэг; зовлон бэрхшээл туулсан ч гэсэн Сатанд ашиглуулж, хууртахыг би хүсэхгүй. Энэхүү бүтээл би Танаар ашиглуулж, Танаар эзэмдүүлж, Танаар шүүгдэж, Танаар гэсгээгдэх ёстой. Би бүр Танаар хараалгах ёстой. Та намайг ерөөхийг хүсэх үед миний зүрх сэтгэл баярлан хөөрдөг, учир нь би Таны хайрыг харсан билээ. Та бол Бүтээгч, би бол бүтээл: би Танаас урваж, Сатаны эзэмшил дор амьдрах ёсгүй, мөн Сатанаар ашиглуулах ч ёсгүй. Сатаны төлөө амьдарсны оронд би Таны морь, эсвэл үхэр байх ёстой. Бие махбодын жаргалгүйгээр Таны гэсгээлтийн дунд амьдрах нь надад илүү дээр бөгөөд Таны нигүүлслийг алдах байсан ч энэ нь надад таашаал авчирна. Таны нигүүлсэл надтай хамт байдаггүй хэдий ч би Танаар гэсгээгдэж, шүүгдэх дуртай; энэ нь Таны хамгийн сайн ерөөл, хамгийн агуу нигүүлсэл билээ. Хэдий Та надад үргэлж сүр жавхлантай, уур хилэнтэй ханддаг ч би Таныг орхин явж чадахгүй, мөн Таныг хангалттай хайрлаж ч чаддаггүй. Би Таны гэрт амьдрахыг илүүд үзнэ, Танаар хараалгаж, гэсгээгдэж, цохиулахыг илүүд үзэх ба Сатаны эзэмшил дор амьдрахыг хүсэхгүй, мөн зөвхөн махан биеийн төлөө яарч, завгүй байхыг ч хүсэхгүй, махан биеийн төлөө амьдрахыг бүр ч хүсэхгүй” гэсэн юм. Петрийн хайр цэвэр ариун хайр байв. Энэ нь төгс болгуулах туршлага, төгс болгуулах хамгийн өндөр түвшин юм; үүнээс илүү утга учиртай амьдрал гэж үгүй. Тэрээр Бурханы гэсгээлт, шүүлтийг хүлээн авсан, Бурханы зөвт зан чанарыг нандигнасан ба үүнээс илүү эрхэм нандин зүйл Петрт байгаагүй. Тэрээр ингэж хэлсэн юм: “Сатан надад материаллаг таашаал өгдөг боловч би тэдгээрийг эрхэмлэдэггүй. Бурханы гэсгээлт, шүүлт над дээр ирдэг—үүнээс би нигүүлсэл хүртдэг, үүнээс би таашаал авдаг, үүгээр би ерөөгддөг. Бурханы шүүлт байгаагүй бол би хэзээ ч Бурханыг хайрлахгүй байсан, би одоо ч Сатаны эзэмшил дор амьдарч, түүгээр хянуулж, удирдуулж байх байсан. Хэрвээ тэгсэн бол, би хэзээ ч жинхэнэ хүн болохгүй байх байсан, учир нь би Бурханыг хангалуун байлгаж чадахгүй, өөрийгөө бүхэлд нь Бурханд зориулахгүй байх байсан. Бурхан намайг ерөөлгүй, дотоод тайтгаралгүйгээр орхиж, дотор минь гал дүрэлзэж байгаа мэт, амар амгалан, баяр хөөргүй байсан ч гэсэн, мөн Бурханы гэсгээлт, сахилгажуулалт хэзээ ч надаас холдоогүй ч гэсэн Бурханы гэсгээлт, шүүлтээс би зөвт зан чанарыг нь харж чаддаг. Би үүнд баярлан бахаддаг; үүнээс илүү үнэ цэнтэй, утга учиртай зүйл амьдралд үгүй. Хэдийгээр Түүний халамж, хамгаалалт нь догшин ширүүн гэсгээлт, шүүлт, хараал, цохилт болсон ч би эдгээр зүйлээс таашаал авсаар байдаг, учир нь тэдгээр нь намайг илүү сайн цэвэрлэж, өөрчилж чадна, намайг

Бурханд илүү ойр аваачиж чадна, Бурханыг илүү хайрладаг болгож чадна, мөн Бурханыг гэх хайрыг минь илүү цэвэр болгож чадна. Энэ нь намайг бүтээлийн үүргээ биелүүлэх боломжтой болгож, намайг Бурханы өмнө аваачиж, Сатаны нөлөөнөөс холдуулж, Сатанд үйлчлэхийг минь болиулдаг. Сатаны эзэмшил дор амьдралгүй, өөртөө байгаа бүхнийг болон өөрийн хийж чадах бүхнийг юуг ч үлдээлгүйгээр Бурханд зориулж чадаж байвал—тэр үед л би бүрэн сэтгэл ханах болно. Бурханы гэсгээлт, шүүлт намайг аварсан бөгөөд миний амьдрал Бурханы гэсгээлт, шүүлтээс салшгүй юм. Газар дээрх миний амьдрал Сатаны эзэмшил дор байдаг бөгөөд Бурханы гэсгээлт, шүүлтийн халамж, хамгаалалт байгаагүй бол би үргэлж Сатаны эзэмшил дор амьдрах байсан, түүнчлэн утга учиртай амьдралыг амьдран харуулах боломж, арга зам ч надад байхгүй байх байсан. Бурханы гэсгээлт, шүүлт намайг хэзээ ч орхихгүй л бол би Бурханаар цэвэрлэгдэж чадна. Бурханы хатуу ширүүн үг, зөвт зан чанар, Бурханы сүр жавхлант шүүлт байснаар л би дээд зэргийн хамгаалалтыг олж авч, гэрэлд амьдрах болж, Бурханы ерөөлийг олж авсан билээ. Цэвэрлэгдэж, өөрийгөө Сатанаас салгаж, Бурханы эрх мэдэл дор амьдарч чаддаг байх—энэ бол энэ насны минь амьдрал дахь хамгийн агуу ерөөл юм.” Энэ нь Петрийн туулсан хамгийн өндөр түвшин билээ.

Төгс болгуулсныхаа дараа хүний хүрэх ёстой байр байдал яг энэ юм. Хэрвээ чи энэ зэрэгт хүрч чадахгүй бол утга учиртай амьдралыг амьдран харуулж чадахгүй. Хүн махан бие дотор амьдардаг нь хүний тамд амьдардаг гэсэн үг бөгөөд Бурханы шүүлт, гэсгээлт байхгүй бол хүн Сатантай адил бохир заваан юм. Хүн яаж ариун байж чадах билээ? Бурханы гэсгээлт болон шүүлт бол хүний хамгийн сайн хамгаалалт, хамгийн агуу нигүүлсэл гэж Петр бодож байв. Бурханы гэсгээлт, шүүлтээр л дамжуулан хүн сэрж, махан биеийг үзэн ядаж, Сатаныг үзэн ядаж чадна. Бурханы хатуу чанд сахилгажуулалт хүнийг Сатаны нөлөөнөөс чөлөөлж, өөрийнх нь жижигхэн ертөнцөөс чөлөөлдөг ба Бурханы гэрэлд хүнийг амьдруулдаг. Гэсгээлт, шүүлтээс илүү дээр аврал гэж үгүй! Петр ийнхүү залбирсан юм: “Өө Бурхан минь! Та намайг гэсгээж, шүүсээр байгаа цагт намайг орхиогүй гэдгийг тань би мэдэх болно. Та надад баяр хөөр, амар амгаланг өгөлгүй, зовлон шаналалд амьдруулж, тоо томшгүй олон цохилт оноож байсан ч гэсэн Та намайг орхиогүй л бол зүрх сэтгэл минь тайван байх болно. Өнөөдөр, Таны гэсгээлт, шүүлт миний хамгийн сайн хамгаалалт, хамгийн агуу ерөөл болсон билээ. Таны өгдөг нигүүлсэл намайг хамгаалдаг. Өнөөдөр Таны надад хайрладаг нигүүлсэл бол Таны зөвт зан чанарын илрэл бөгөөд энэ нь гэсгээлт, шүүлт юм; түүнчлэн энэ нь шалгалт, түүнээс ч илүүтэйгээр зовлонгийн амьдрал билээ.” Петр махан биеийн зугаа цэнгэлийг хойш тавьж, илүү гүн гүнзгий хайрыг, илүү их хамгаалалтыг эрж хайж чадсан, учир нь тэр Бурханы гэсгээлт, шүүлтээс маш их нигүүлслийг олж авсан билээ. Хүн амьдралдаа цэвэрлэгдэж, зан чанартаа өөрчлөлт гаргахыг хүсвэл, утга учиртай амьдралыг амьдран харуулж, бүтээлийн үүргээ биелүүлэхийг хүсвэл Сатаны явуулга, нөлөөллөөс ангижирч, Бурханы гэрэлд амьдрахын тулд Бурханы гэсгээлт,

шүүлтийг хүлээн авах ёстой ба Бурханы сахилгажуулалт, цохилтыг өөрөөсөө холдуулах ёсгүй. Бурханы гэсгээлт, шүүлт бол гэрэл, хүний авралын гэрэл бөгөөд хүний хувьд хамгийн сайн ерөөл, хамгийн агуу нигүүлсэл, хамгийн сайн хамгаалалт. Хүн Сатаны нөлөөн дор амьдарч, махан биед оршдог; хэрвээ тэр цэвэрлэгдэхгүй, мөн Бурханы хамгаалалтыг хүлээн авдаггүй бол улам илүү доройтно. Хэрвээ хүн Бурханыг хайрлахыг хүсдэг бол цэвэрлэгдэж, аврагдах ёстой. Петр ийнхүү залбирсан: “Бурхан минь, надад элэгсэг хандах үед тань би баярлан хөөрч, тайтгарлыг мэдэрдэг; Та намайг гэсгээх үед би бүр ч их тайтгарал, баяр хөөрийг мэдэрдэг. Хэдий би сул дорой байж, үгээр хэлэхийн аргагүй зовлон туулж байгаа ч, хэдийгээр нулимс, уйтгар гуниг байдаг ч гэсэн, энэхүү уйтгар гуниг нь миний дуулгаваргүй байдлаас болдог, миний сул доройгоос болдог гэдгийг Та мэднэ. Таны хүслийг хангаж чаддаггүй учраас би уйлдаг, Таны шаардлагад хүрч чадахгүй учраас би уй гашуу, харууслыг мэдэрдэг, гэхдээ би энэ түвшинд хүрэхэд бэлэн байна, Таныг сэтгэл хангалуун байлгахын тулд чадах бүхнээ хийхэд бэлэн байна. Таны гэсгээлт надад хамгаалалт авчирч, хамгийн сайн авралыг өгсөн; Таны шүүлт тэсвэр, тэвчээрийг тань даван гардаг. Таны гэсгээлт, шүүлтгүйгээр би Таны өршөөл, өгөөмөр сэтгэлийг эдлэхгүй байх байсан. Өнөөдөр, Таны хайр тэнгэрүүдийг даван гарсан ба бусад бүх зүйлээс илүү давдгийг би бүр ч сайн хардаг. Таны хайр бол зөвхөн өршөөл, хайр энэрэл биш; үүнээс ч илүүтэйгээр гэсгээлт, шүүлт билээ. Таны гэсгээлт, шүүлтээс би маш ихийг олсон. Таны гэсгээлт, шүүлтгүйгээр нэг ч хүн цэвэрлэгдэхгүй байсан, мөн нэг ч хүн Бүтээгчийн хайрыг мэдэрч чадахгүй байх байсан. Хэдийгээр би хэдэн зуун шалгалт, зовлон шаналлыг туулж, бүр үхэхдээ тулсан ч гэсэн, Таныг үнэхээр мэдэж, дээд зэргийн авралыг олж авах боломжийг энэ нь надад олгосон. Хэрвээ Таны гэсгээлт, шүүлт, сахилгажуулалт намайг орхисон бол би Сатаны эзэмшил дор харанхуйд амьдрах байлаа. Хүний махан бие ямар ашигтай юм бэ? Хэрвээ Таны гэсгээлт, шүүлт намайг орхисон бол Таны Сүнс намайг орхисонтой адил, Та надтай хамт байхаа больсонтой адил байх байлаа. Хэрвээ тийм байсан бол би яаж үргэлжлүүлэн амьдарч чадах билээ? Хэрвээ Та надад өвчин өгч, эрх чөлөөг минь авах юм бол би үргэлжлүүлэн амьдарч чадна, харин Таны гэсгээлт, шүүлт намайг орхивол би амьдрах ямар ч аргагүй болох байсан. Хэрвээ надад Таны гэсгээлт, шүүлт байгаагүй бол Таны хайрыг алдах байсан. Таны хайр бол дэндүү гүн гүнзгий, үгээр илэрхийлэхийн аргагүй хайр билээ. Таны хайр байхгүй бол би Сатаны эзэмшил дор амьдарч, Таны суу алдарт царайг харж чадахгүй байх байсан. Би яаж үргэлжлүүлэн амьдарч чадах билээ? Тийм харанхуй байдал, тийм амьдралыг би тэвчиж чадахгүй. Тантай хамт байгаа нь Таныг харахтай адил тул би Таныг яаж орхиж чадах билээ? Би Танаас гуйя, санаа амраасан хэдхэн үг байлаа ч гэсэн миний хамгийн их тайвшралыг надаас бүү аваач гэж би Танаас хүсэж байна. Би Таны хайрыг эдэлсэн ба өнөөдөр би Танаас хол байж чадахгүй; би Таныг хайрлахгүй байж яахан чадах билээ? Таны хайраас болж би уй гашуугийн ихээхэн нулимс

урсгасан, гэсэн ч тийм амьдрал нь илүү утга учиртай, мөн намайг илүү их баяжуулж, намайг илүү их өөрчилж чадах ба бүтээлийн эзэмших ёстой үнэнд хүрэх боломжийг надад олгож чадна гэдгийг би үргэлж мэдэрдэг байсан.”

Хүн бүхий л амьдралдаа Сатаны эзэмшил дор амьдардаг, өөрөө Сатаны нөлөөнөөс ангижирч чадах хүн нэг ч үгүй. Бүгд өчүүхэн ч утга учиргүй, эсвэл үнэ цэнгүйгээр бохир заваан дэлхийд, завхрал, хоосрол дунд амьдардаг; тэд махан биеийн төлөө, шунал тачаалын төлөө, Сатаны төлөө тийм хэнэггүй амьдралаар амьдардаг. Тэдний оршин тогтнолд өчүүхэн төдий ч үнэ цэн үгүй. Өөрийг нь Сатаны нөлөөнөөс чөлөөлөх үнэнийг хүн олж авч чадахгүй. Хэдийгээр хүн Бурханд итгэж, Библи уншдаг ч өөрийгөө Сатаны нөлөөний хяналтаас хэрхэн чөлөөлөхийг ойлгодоггүй. Эрин үеүдийн туршид маш цөөхөн хүн энэ нууцыг олж илрүүлсэн, тун цөөн хүн үүнийг ухаарсан. Ийм болохоор, хэдийгээр хүн Сатаныг жигшиж, махан биеийг жигшдэг ч Сатаны урхидалтын нөлөөллөөс хэрхэн ангижрахаа мэддэггүй. Өнөөдөр, та нар Сатаны эзэмшил дор байсаар байгаа бус уу? Дуулгаваргүй үйлдэлдээ та нар гэмшдэггүй, бохир заваан, дуулгаваргүй гэдгээ бүр ч мэдэрдэггүй. Бурханыг эсэргүүцсэнийхээ дараа ч гэсэн сэтгэл амар байж, асар их амар амгаланг мэдэрдэг. Энэхүү амгалан байдал нь завхарсан байдлаас чинь болдоггүй гэж үү? Энэхүү санаа амар байдал дуулгаваргүй байдлаас чинь гардаггүй гэж үү? Хүмүүс хүний тамд амьдардаг, Сатаны харанхуй нөлөөн дор амьдардаг; газар нутаг даяар сүнснүүд хүнтэй хамт амьдарч, хүний махан бие рүү бага багаар халдан довтолдог. Газар дээр чи үзэсгэлэнтэй сайхан диваажинд амьдардаггүй. Чиний байгаа газар бол диаволын ертөнц, хүний там, үхэгсдийн ертөнц юм. Хэрвээ хүн цэвэрлэгдэхгүй бол бохир заваан байдаг; хэрвээ тэр Бурханаар хамгаалуулж, халамжлуулахгүй бол Сатаны хоригдол хэвээр үлддэг; хэрвээ шүүгдэж, гэсгээгдэхгүй бол Сатаны харанхуй нөлөөний дарлалаас зугтах ямар ч аргагүй байх болно. Чиний харуулдаг завхарсан зан чанар болон амьдран харуулдаг дуулгаваргүй зан авир Сатаны эзэмшил дор амьдарсаар байгааг чинь батлахад хангалттай. Хэрвээ чиний оюун санаа болон бодол цэвэрлэгдээгүй бол, мөн чиний зан чанар шүүгдэж, гэсгээгдээгүй бол бүхий л оршихуй чинь Сатаны эзэмшлийн хяналтад байж, оюун санаа чинь Сатанд захирагдах ба бодлыг чинь Сатан зохион байгуулж, бүх оршихуйг чинь Сатаны гар хянаж байдаг. Чи одоо Петрийн стандартаас яг хэр хол байгаагаа мэдэж байна уу? Чамд тийм хэв чанар байгаа юу? Чи өнөөдрийн гэсгээлт, шүүлтийг хэр их мэддэг вэ? Петрийн мэдэж авсан зүйлийн хэр ихийг эзэмшдэг вэ? Хэрвээ өнөөдөр чи мэдэж авч чадахгүй бол ирээдүйд энэ мэдлэгийг олж авч чадах уу? Чам шиг залхуу, хулчгар хүмүүс гэсгээлт, шүүлтийг ердөө ч мэдэх чадваргүй. Хэрвээ чи махан биеийн амар тайван, махан биеийн зугаа цэнгэлээр хөөцөлдвөл цэвэрлэгдэх ямар ч аргагүй байх ба эцэст нь Сатан руу эргэн очно, учир нь чиний амьдран харуулдаг зүйл бол Сатан, мөн махан бие билээ. Өнөөдрийн байдлаар олон хүн амийг эрэлхийлдэггүй ба тэд ариусгагдах тухай, эсвэл илүү гүн гүнзгий амийн туршлага руу орох тухай

анхаардаггүй гэсэн үг юм. Тийм болохоор тэд яаж төгс болгуулж чадах юм бэ? Амийг эрэлхийлдэггүй хүмүүст төгс болгуулах ямар ч боломж байхгүй бөгөөд Бурханы тухай мэдлэгийг эрэлхийлдэггүй, зан чанараа өөрчлөхийг зорьдоггүй хүмүүс Сатаны харанхуй нөлөөнөөс зугтаах чадваргүй байдаг. Зүгээр л зан үйл мөрдөж, ердийн үйл ажиллагаанд оролцдог шашны итгэгчдийн адилаар тэд Бурханыг мэдэх болон зан чанарын өөрчлөлтөд орох талаар нухацтай ханддаггүй. Энэ нь цагийн гарз биш гэж үү? Хэрвээ Бурханд итгэх итгэлдээ хүн, амийн асуудлуудад нухацтай ханддаггүй, үнэн рүү орохоор эрэлхийлдэггүй, зан чанараа өөрчлөхийг ч зорьдоггүй, тэр ч байтугай Бурханы ажлын талаарх мэдлэгийг эрж хайдаггүй бол төгс болгуулж чадахгүй. Хэрвээ чи төгс болгуулахыг хүсэж байвал Бурханы ажлыг ойлгох ёстой. Ялангуяа Түүний гэсгээлт, шүүлтийн ач холбогдлыг, мөн энэ ажлыг яагаад хүн дээр хийдгийг ойлгох ёстой. Чи үүнийг хүлээн авч чадах уу? Ийм төрлийн гэсгээлтийн үеэр чи Петртэй адилхан туршлага, мэдлэгийг олж авч чадах уу? Хэрвээ чи Бурханы тухай болон Ариун Сүнсний ажлын тухай мэдлэгийг эрэлхийлж, зан чанартаа өөрчлөлт хийхээр зорьдог бол төгс болгуулах боломж олдоно.

Төгс болгуулах хүмүүсийн хувьд байлдан дагуулагдах ажлын энэ алхам зайлшгүй шаардлагатай; хүн байлдан дагуулагдмагцаа л төгс болгуулах ажлыг туулж чадна. Зөвхөн байлдан дагуулагдах үүргийг л биелүүлэх нь тийм ч их үнэ цэнтэй биш бөгөөд Бурханаар ашиглуулахад тохирохгүй. Чи сайн мэдээ түгээхэд хувь нэмэр оруулах ямар ч аргагүй байх болно, учир нь чи амийг эрэлхийлдэггүй, өөрийгөө өөрчилж, шинэчлэхээр эрэлхийлдэггүй, иймээс чамд амийн ямар ч бодит туршлага байдаггүй. Энэхүү алхам алхмаар хийгддэг ажлын үеэр чи нэгэнтээ үйлчлэл үзүүлэгч, товойлгогч болж ажилласан боловч эцэстээ Петр шиг байхыг зорьдоггүй, мөн эрэл хайгуул чинь Петрийн төгс болгуулсан замын дагуу байдаггүй бол мэдээж зан чанарын өөрчлөлтийг туулахгүй. Хэрвээ чи төгс болгуулахыг зорьдог хүн бол гэрчлэл хийсэн байх ба ингэж хэлэх болно: “Алхам алхмаар хийгддэг Бурханы энэ ажилд би Бурханы гэсгээлт, шүүлтийг хүлээн авсан бөгөөд асар их зовлон туулсан хэдий ч Бурхан хүнийг хэрхэн төгс болгодгийг мэдэж авсан, Бурханы хийдэг ажлыг олж авсан, Бурханы зөвт байдлын тухай мэдлэгтэй болсон ба Түүний гэсгээлт намайг аварсан. Түүний зөвт зан чанар над дээр ирж, надад ерөөл, нигүүлсэл авчирсан; Түүний гэсгээлт, шүүлт л намайг хамгаалж, ариусгасан. Хэрвээ намайг Бурхан гэсгээж, шүүгээгүй бол, хэрвээ Бурханы хатуу ширүүн үг над дээр ирээгүй бол би Бурханыг мэдэж чадахгүй байх байсан, аврагдаж ч чадахгүй байх байсан. Бүтээгдсэн зүйлийн хувиар хүн Бүтээгчийн бүтээсэн бүх зүйлийг эдлээд зогсохгүй, хамгийн чухал нь бүх бүтээл Бурханы зөвт зан чанар болон зөвт шүүлтийг эдлэх ёстой, учир нь Бурханы зан чанар хүний таашаалыг хүртүүштэй гэдгийг би өнөөдөр харж байна. Сатаны завхруулсан бүтээл болохын хувьд хүн Бурханы зөвт зан чанарыг эдлэх ёстой. Түүний зөвт зан чанарт гэсгээлт, шүүлт байдаг, түүнчлэн агуу хайр байдаг. Хэдийгээр би өнөөдөр Бурханы хайрыг бүрэн

дүүрэн олж авч чадахгүй байсан ч үүнийг харах сайн хувь тавилантай байсан ба үүгээр би ерөөгдсөн.” Энэ бол төгс болгуулсан хүмүүсийн алхсан зам бөгөөд тэдний ярьдаг мэдлэг юм. Ийм хүмүүс Петртэй адил; тэд Петртэй адил туршлагатай. Ийм хүмүүс бас амийг олж авсан, үнэнийг эзэмшдэг хүмүүс юм. Тэд бүр эцсийг нь хүртэл туулах үедээ Бурханы шүүлтийн үеэр Сатаны нөлөөнөөс бүрмөсөн ангижирч, Бурханаар авхуулах нь гарцаагүй.

Байлдан дагуулагдсаны дараа хүмүүст ямар ч цангинасан гэрчлэл байдаггүй. Тэд ердөө л Сатаныг шившиглэсэн, гэхдээ Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулаагүй. Чи хоёр дахь авралыг олж аваагүй; зүгээр л нүглийн тахилыг олж авсан, гэхдээ хараахан төгс болгуулаагүй—энэ нь асар их хохирол юм. Та нар юунд орох ёстойгоо, юуг амьдран харуулах ёстойгоо ойлгох учиртай ба тэдгээрт орох ёстой. Хэрвээ эцэст нь төгс болгуулж чадахгүй бол чи жинхэнэ хүн болохгүй ба харууслаар дүүрнэ. Анх Бурханы бүтээсэн Адам, Ева хоёр ариун хүмүүс байсан, өөрөөр хэлбэл, Еден цэцэрлэгт байх үедээ тэд бохир заваанаар сэвтээгүй, ариун байсан. Тэд бас Еховад итгэлтэй, Еховагаас урвах талаар юу ч мэддэггүй байв. Яагаад гэвэл, тэд Сатаны нөлөөллийн үймээнд автаагүй, Сатаны хоргүй байсан бөгөөд бүх хүн төрөлхтнөөс хамгийн ариун нь байлаа. Тэд ямар ч бузраар бохирдолгүй, махан биед эзэмдүүлэлгүй, Еховаг хүндлэн дээдэлж, Еден цэцэрлэгт амьдардаг байжээ. Дараа нь Сатанд уруу татагдах үедээ тэд могойн хортой, Еховагаас урвах хүсэлтэй болж, Сатаны нөлөөн дор амьдарсан юм. Эхэн үедээ тэд ариун байсан бөгөөд Еховаг хүндэлдэг байсан; ийм байр байдалд л тэд хүн байв. Сүүлд нь, Сатанд уруу татагдсаныхаа дараа тэд сайн мууг мэдүүлэгч модны жимсийг идэж, Сатаны нөлөөн дор амьдарсан. Тэд аажмаар Сатаны завхралд өртөж, хүний анхдагч дүр төрхийг алдсан юм. Анх хүнд Еховагийн амьсгал байсан бөгөөд өчүүхэн төдий ч дуулгаваргүй байгаагүй, мөн зүрх сэтгэлд нь өчүүхэн төдий ч ёрын муу байгаагүй. Тэр үед, хүн үнэхээр хүн байсан. Сатанаар завхруулагдсаныхаа дараа хүн араатан болсон юм. Түүний бодол ёрын муу, бузраар дүүрч, ямар ч сайн сайхан, ариун байдалгүй болсон. Энэ нь Сатан биш гэж үү? Бурханы ихээхэн ажлыг туулсан боловч чи өөрчлөгдөөгүй, эсвэл цэвэрлэгдээгүй. Чи Сатаны эзэмшил дор амьдарсаар байдаг ба Бурханд мөн л захирагддаггүй. Энэ бол байлдан дагуулагдсан боловч төгс болгуулаагүй хүн юм. Тийм хүнийг яагаад төгс болгуулаагүй гэдэг вэ? Учир нь энэ хүн амийг буюу Бурханы ажлын тухай мэдлэгийг эрэлхийлдэггүй бөгөөд зөвхөн махан биеийн зугаа цэнгэл, түр зуурын тав тухад шунадаг. Үүний үр дүнд, тэдний амь зан чанарт ямар ч өөрчлөлт байдаггүй ба тэд Бурханаар бүтээгдсэн хүний анхдагч дүр төрхийг олж аваагүй. Тийм хүмүүс бол алхаж яваа цогцос, ямар ч сүнсгүй үхдэлүүд юм! Сүнсэн дэх хэрэг явдлын тухай мэдлэгийг эрэлхийлдэггүй, ариун байдлыг эрэлхийлдэггүй, үнэнийг амьдран харуулахаар зорьдоггүй, зөвхөн сөрөг талд байлдан дагуулагдахад л сэтгэл ханадаг, Бурханы үгээр амьдарч, ариун хүмүүс болж чаддаггүй хүмүүс бол аврагдаагүй хүмүүс билээ. Учир нь, хэрвээ хүнд үнэн

байхгүй бол Бурханы шалгалтын үеэр бат зогсож чадахгүй; Бурханы шалгалтын үеэр бат зогсож чадах хүмүүс л аврагдсан хүмүүс юм. Би Петр шиг хүмүүсийг, төгс болгуулахаар зорьдог хүмүүсийг л хүсдэг. Өнөөдрийн үнэн нь, үүнийг эрж хайж, хүсэн тэмүүлдэг хүмүүст өгөгддөг. Энэхүү аврал нь Бурханаар аврууулахыг хүсэн тэмүүлдэг хүмүүст өгөгддөг ба зөвхөн та нар үүнийг олж авах учиртай юм биш. Бурхан ч гэсэн та нарыг олж авах нь үүний зорилго юм; та нар Бурханаар авхуулахын тулд Бурханыг олж авдаг. Өнөөдөр Би эдгээр үгийг та нарт хэлж, та нар үүнийг сонссон, тэгээд та нар эдгээр үгийн дагуу хэрэгжүүлэх ёстой. Эцэст нь, эдгээр үгийг хэрэгжүүлэх үе чинь эдгээр үгээр дамжуулаад Би та нарыг олж авах үе байх болно; үүний зэрэгцээ та нар ч бас эдгээр үгийг олж авсан байна, өөрөөр хэлбэл, та нар дээд зэргийн энэхүү авралыг олж авсан байх болно. Цэвэрлэгдмэгцээ та нар жинхэнэ хүн болсон байх болно. Хэрвээ чи үнэнийг амьдран харуулж, эсвэл төгс болгуулсан нэгний төрхийг амьдран харуулах чадваргүй бол чамайг хүн биш, харин алхаж яваа цогцос, араатан гэж хэлж болно, учир нь чи үнэнгүй буюу Еховагийн амьсгалгүй хүн тул ямар ч сүнсгүй үхсэн хүн юм! Хэдийгээр байлдан дагуулагдсаны дараа гэрчлэл хийх боломжтой ч олж авсан зүйл чинь өчүүхэн аврал төдий бөгөөд чи сүнстэй амьд оршихуй болоогүй. Хэдийгээр чи гэсгээлт, шүүлт туулсан ч үүний үр дүнд зан чанар чинь шинэчлэгдэж, өөрчлөгдөөгүй; чи одоо ч хуучнаараа байгаа, одоо ч Сатанд харьяалагддаг ба цэвэрлэгдсэн хүн биш. Төгс болгуулсан хүмүүс л үнэ цэнтэй бөгөөд тийм хүмүүс л жинхэнэ амьдралыг олж авсан. Нэг л өдөр хэн нэгэн хүн чамд ингэж хэлэх болно: “Чи Бурханы ажлыг туулсан юм чинь Түүний ажил ямархуу болохыг яриад өгөөч. Давид Бурханы ажлыг туулж, Еховагийн үйл хэргийг харсан, Мосе ч гэсэн Еховагийн үйл хэргийг харсан бөгөөд тэр хоёр Еховагийн үйл хэргийг дүрсэлж чаддаг байсан, мөн Еховагийн гайхалтай байдлын талаар ярьж чадсан. Та нар бие махбодтой болсон Бурханы эцсийн өдрүүдэд хийсэн ажлыг харсан; чи Түүний мэргэн ухааны талаар ярьж чадах уу? Түүний ажлын гайхалтай байдлын талаар ярьж чадах уу? Бурхан та нарт ямар шаардлага тавьсан бэ, та нар тэдгээрийг хэрхэн туулсан бэ? Та нар эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг туулсан—та нарын хамгийн агуу үзэгдэл юу вэ? Та нар энэ тухай ярьж чадах уу? Бурханы зөвт зан чанарын тухай ярьж чадах уу?” Эдгээр асуулттай тулгарах үедээ чи хэрхэн хариулах вэ? Хэрвээ чи: “Бурхан үнэхээр зөвт, Тэр биднийг гэсгээж, шүүдэг ба биднийг өршөөлгүйгээр ил болгодог; Бурханы зан чанар хүний халдлагыг үнэхээр тэвчдэггүй; Бурханы ажлыг туулсныхаа дараа би араатан шиг байдлаа мэдэж авч, Бурханы зөвт зан чанарыг үнэхээр харсан” гэж хэлбэл өнөөх хүн чамаас: “Чи Бурханы талаар өөр юу мэдэх вэ? Хүн яаж амь руу ордог юм бэ? Чамд ямар нэг хувийн хүсэл эрмэлзэл байгаа юу?” хэмээн үргэлжлүүлэн асууна. Чи: “Сатанаар завхруулагдсаныхаа дараа Бурханы бүтээлүүд араатан болж, илжигнээс өөрцгүй болсон. Өнөөдөр би Бурханы гарт амьдардаг тул Бүтээгчийн хүслийг хангаж, заасан бүхнийг нь дуулгавартай дагах ёстой. Надад өөр сонголт байхгүй” гэж

хариулна. Хэрвээ чи ийм ерөнхий зүйл ярих юм бол тэр хүн юу яриад байгааг чинь ойлгохгүй. Бурханы ажлын талаар ямар мэдлэгтэйг чинь асуух үедээ тэр хувийн туршлагыг чинь хэлж байгаа юм. Бурханы гэсгээлт, шүүлтийг туулсны дараа энэ талаар ямар мэдлэгтэй болсныг чинь тэр асууж байгаа, үүгээрээ хувийн туршлагыг чинь хэлж байгаа ба үнэний талаарх мэдлэгээ ярихыг чамаас хүсэж байгаа юм. Хэрвээ чи ийм зүйлсийн талаар ярьж чадахгүй бол өнөөдрийн ажлын талаар юу ч мэддэггүйг чинь энэ нь баталдаг. Чи үргэлж хуурмаг зүйлийг, эсвэл нийтээрээ мэддэг зүйлийг л ярьдаг; чамд нарийн тодорхой туршлага байхгүй, мэдлэгт чинь мөн чанар бүр ч байхгүй, бас чамд ямар ч жинхэнэ гэрчлэл байхгүй тул бусад хүн чамд үнэмшдэггүй. Бурханы идэвхгүй дагагч бүү бай, чамайг сониуч болгох зүйлсийг бүү эрэлхийл. Халуун ч биш, хүйтэн ч биш байснаараа чи өөрийгөө сүйрүүлж, амиа саатуулна. Чи тийм идэвхгүй зогсонги байдлаасаа салж, эерэг зүйлсийг эрэлхийлж, сул талуудаа даван гарахад сурамгай болох ёстой, ингэснээр чи үнэнийг олж авч, үнэнийг амьдран харуулж болох юм. Чиний сул талын хувьд айх юм юу ч байхгүй ба чиний дутагдал хамгийн том асуудал чинь биш. Харин тэр халуун ч биш, хүйтэн ч биш байж, үнэнийг эрж хайх хүсэлгүй байдаг чинь хамгийн том асуудал, хамгийн том дутагдал юм. Та бүхний хамгийн том асуудал бол байгаа байдалдаа сэтгэл ханамжтай байж, зүгээр л идэвхгүйгээр хүлээдэг тэр хулчгар сэтгэхүй юм. Энэ нь та нарын хамгийн том саад бартаа бөгөөд үнэний эрэл хайгуулын чинь хамгийн том дайсан билээ. Миний хэлдэг үг маш гүн гүнзгий учраас л дуулгавартай дагадаг бол чи үнэхээр мэдлэгтэй хүн биш, мөн үнэнийг нандигнадаг хүн ч биш. Чинийх шиг дуулгавартай байдал бол гэрчлэл биш бөгөөд Би тийм дуулгавартай байдлыг сайшаадаггүй. Хэн нэгэн чамаас, “Чиний Бурхан яг хаанаас ирсэн бэ? Чиний энэ Бурханы мөн чанар юу вэ?” гэж асууж магадгүй. “Түүний мөн чанар бол гэсгээлт, шүүлт” гэж чи хариулна. Тэгэхэд тэрээр үргэлжлүүлэн “Бурхан хүнд энэрэнгүй, хайр энэрэлтэй ханддаг биш үү? Чи үүнийг мэдэхгүй гэж үү?” гэхэд чи: “Тэр бол бусдын Бурхан. Энэ нь шашны хүмүүсийн итгэдэг Бурхан болохоос манай Бурхан биш” гэж хариулна. Чам шиг хүмүүс сайн мэдээ түгээх үедээ үнэн замыг гуйвуулдаг, тэгвэл чи ямар хэрэгтэй юм бэ? Бусад хүмүүс яаж үнэн замыг чамаас олж авч чадах юм бэ? Чи үнэнгүй бөгөөд үнэний талаар юу ч ярьж чадахгүй, түүнчлэн үнэнийг амьдран харуулж ч чадахгүй. Чи Бурханы өмнө амьдрахад яаж тохирох юм бэ? Сайн мэдээг бусдад түгээх үедээ, үнэний тухай нөхөрлөж, Бурханд гэрчлэл хийх үедээ хэрвээ чи тэднийг үнэмшүүлж чадахгүй бол тэд үгийг чинь няцаах болно. Чи хог хаягдал биш үү? Чи Бурханы ажлаас маш ихийг туулсан ч үнэний талаар ярьж байгаа чинь ямар ч утгагүй байдаг. Чи ямар ч хэрэггүй биш үү? Ямар хэрэгтэй юм бэ? Та нар Бурханы ажлыг маш их туулсан мөртөө Түүний талаар өчүүхэн төдий ч мэдлэггүй байж яаж чадаж байна вэ? Бурханы талаар ямар бодит мэдлэгтэйг чинь асуухад чи хэлэх ч үггүй болж, эсвэл хамаагүй зүйл ярьж—Бурхан бол сүр хүчтэй, чиний хүлээн авсан агуу ерөөлүүд бол үнэхээр Бурханы өргөмжлөл, мөн Бурханыг биечлэн харж чаддаг

байхаас илүү нэр төрийн хэрэг гэж үгүй хэмээн хариулдаг. Ингэж хэлэх нь ямар үнэ цэнтэй юм бэ? Тэдгээр нь хэрэггүй, дэмий хоосон үг! Бурханы маш их ажлыг туулчхаад чи Бурханы өргөмжлөл бол үнэн гэдгийг л мэдсэн юм уу? Чи Бурханы ажлыг мэдэх ёстой, тэр үед л чи Бурханд жинхэнэ гэрчлэл хийж чадна. Үнэнийг олж аваагүй хүмүүс Бурханд гэрчлэл хийж яаж чадах юм бэ?

Хэрвээ ийм их ажил, ийм их үг чамд ямар ч үр нөлөө үзүүлээгүй бол Бурханы ажлыг түгээх цаг ирэх үед чи үүргээ биелүүлж чадахгүй ба ичгүүр гутамшигт автана. Тэр үед чи Бурханд маш их өртэйгөө, мөн Бурханы талаарх мэдлэг чинь маш өнгөц гэдгийг мэдэрнэ. Хэрвээ чи өнөөдөр Бурханыг ажиллаж байх зуур Бурханы тухай мэдлэгийг эрэлхийлдэггүй бол дараа нь хэтэрхий оройтсон байх болно. Эцэст нь чамд ярих мэдлэг юу ч байхгүй байна—чи юу ч үгүй, хоосон үлдэнэ. Тэгвэл чи Бурханд тайлан өгөхдөө юу ашиглах юм бэ? Бурханыг харах нүүр чамд байна гэж үү? Чи яг одоо эрэл хайгуулдаа шаргуу ажиллах ёстой, ингэснээр эцэст нь Петр шиг, Бурханы гэсгээлт, шүүлт хүнд яг ямар ашиг тустай болохыг, мөн Түүний гэсгээлт, шүүлтгүйгээр хүн аврагдаж чадахгүй, энэ бохир заваан газарт, шавар шавхайд бүр ч гүн шигдэнэ гэдгийг ойлгох болно. Хүмүүс Сатанаар завхруулагдаж, нэг нэгнийхээ эсрэг явуулга хийж, нэг нэгнээ уландаа гишгэлж, Бурханаас эмээхээ больсон. Тэдний дуулгаваргүй байдал хэтэрхий их, үзэл нь дэндүү олон бөгөөд бүгд Сатанд харьяалагддаг. Бурханы гэсгээлт, шүүлтгүйгээр хүний завхарсан зан чанарыг цэвэрлэх боломжгүй ба хүн аврагдаж чадахгүй. Бие махбодтой болсон Бурханы махбод дахь ажлаар илэрхийлэгддэг зүйл нь яг нарийндаа Сүнсний илэрхийлдэг зүйл бөгөөд Түүний хийдэг ажил Сүнсний хийдэг зүйлийн дагуу явагддаг. Өнөөдөр, хэрвээ энэ ажлын тухай юу ч мэддэггүй бол чи маш мунхаг бөгөөд маш ихийг алджээ! Хэрвээ чи Бурханы авралыг олж аваагүй бол итгэл чинь шашны итгэл бөгөөд чи бол шашны Христэд итгэгч юм. Чи үхмэл сургаалыг баримталдаг учраас Ариун Сүнсний шинэ ажлыг алдсан; Бурханыг хайрлахаар эрэлхийлдэг бусад хүмүүс үнэн болон амийг олж авч чаддаг байхад чиний итгэл Бурханы сайшаалыг хүртэх чадваргүй. Харин ч чи мууг үйлдэгч буюу муу үр дагавартай, заналт үйл үйлддэг хүн болсон; мөн Сатаны тоглоом тохуу болж, Сатаны хоригдол болсон. Бурхан бол хүнээр итгүүлэхийн тулд биш, харин хүнээр хайрлуулахын тулд, шүтэн мөргүүлж, эрж хайлгахын тулд байдаг. Хэрвээ чи өнөөдөр эрэлхийлдэггүй бол “Тэр үед би яагаад Бурханыг зохих ёсоор дагаж, зохих ёсоор хангалуун байлгаж, амь зан чанартаа өөрчлөлт хийхийг зорьсонгүй вэ? Тухайн үед Бурханд захирагдаж чадаагүйдээ, Бурханы үгийн тухай мэдлэгийг эрэлхийлээгүйдээ би үнэхээр харамсаж байна. Бурхан тэр үед маш ихийг хэлсэн; би яагаад эрэлхийлж чадаагүй юм бол оо? Би маш тэнэг байжээ!” гэж хэлэх өдөр ирэх болно. Чи тодорхой хэмжээнд өөрийгөө үзэн ядна. Өнөөдөр чи Миний хэлдэг үгэнд итгэдэггүй, тэдгээрт огт анхаарал хандуулдаггүй; энэхүү ажил түгэх өдөр ирэх үед чи үүнийг бүхэлд нь хараад харамсана, тэгээд тэр үед цочин мэгдэнэ. Ерөөл байгаа ч чи хэрхэн эдлэхээ мэддэггүй, үнэн байгаа ч чи эрэлхийлдэггүй. Чи

өөрийгөө басамжилж байгаа бус уу? Өнөөдөр, Бурханы ажлын дараагийн алхам хараахан эхлээгүй байгаа хэдий ч чамд тавьсан шаардлага, амьдран харуул гэж чамаас шаардсан зүйлд ямар ч илүүц зүйл байхгүй. Маш их ажил, маш их үнэн байгаа; тэдгээрийг чи мэдвэл зохистой бус уу? Бурханы гэсгээлт, шүүлт чиний сүнсийг сэрээх чадваргүй гэж үү? Бурханы гэсгээлт, шүүлт чамайг өөрийгөө үзэн ядахад хүргэх чадваргүй гэж үү? Чи Сатаны нөлөөн дор амар амгалан, баяр хөөртэй, бие махбодын багахан тав тухтай байдалд амьдрахдаа сэтгэл хангалуун байна уу? Чи бүх хүнээс хамгийн дорд муу нь биш гэж үү? Авралыг харсан мөртөө үүнийг олж авахаар зорьдоггүй хүмүүс бол хамгийн тэнэг хүмүүс; тэд бол махан биеийн хүсэлд шунадаг, Сатаныг таашаадаг хүмүүс юм. Бурханд итгэх итгэл чинь ямар ч төвөгтэй байдал, гай зовлон, өчүүхэн төдий ч хүндрэл бэрхшээлд хүргэхгүй гэж чи найддаг. Чи дандаа эдгээр үнэ цэнгүй зүйлийг эрэлхийлдэг ба амийг ямар ч үнэ цэнгүй гэж үзээд, харин хэрээс хэтэрсэн бодлоо үнэнээс түрүүнд тавьдаг. Чи үнэхээр үнэ цэнгүй! Чи гахай шиг амьдардаг—чи гахай, нохойноос ямар ялгаатай юм бэ? Үнэнийг эрэлхийлдэггүй, харин махан биеийг л хайрладаг хүмүүс бүгд араатан биш гэж үү? Сүнсгүй үхдэлүүд бүгд алхаж яваа цогцос биш гэж үү? Та нарын дунд хэчнээн их үг яригдсан бэ? Та нарын дунд хийгдсэн ажил өчүүхэн төдий гэж үү? Та нарын дунд Би хэчнээн ихийг өгсөн бэ? Тэгвэл чи яагаад үүнийг олж аваагүй юм бэ? Чамд гомдоллох зүйл юу байгаа юм бэ? Чи махан биеийг хэтэрхий их хайрладаг учраас юу ч олж аваагүй биш гэж үү? Чиний бодол хэтэрхий туйлширснаас энэ нь болсон бус уу? Хэтэрхий тэнэгээс чинь болсон бус уу? Хэрвээ чи эдгээр ерөөлийг олж авч чадахгүй бол чамайг авраагүйн төлөө Бурханыг буруутгаж болох уу? Чиний эрэлхийлдэг зүйл бол Бурханд итгэснийхээ дараа амар амгаланг олж чадах явдал, хүүхдүүд чинь өвчин хуучаас ангид байх, нөхөр чинь сайн ажилтай байх, хүү чинь сайн эхнэр олж авах, охин чинь дажгүй нөхөртэй болох, үхэр адуу чинь газраа сайн хагалах, ургац ургахын тулд жилийн турш цаг агаар сайхан байх. Чиний эрэлхийлдэг зүйл энэ. Чиний эрэл хайгуул зөвхөн тав тухтай амьдрахын төлөө байдаг, мөн ямар ч осол танай гэр бүлд тохиолдохгүй байх, салхи шуурга хажуугаар чинь өнгөрөх, нүүр царайд чинь элс шороо хүрэхгүй байх, ургац чинь үерт автахгүй байх, ямар ч гамшигт нэрвэгдэхгүй байх, Бурханы тэвэрт амьдрах, тохитой гэр оронд амьдрахын төлөө байдаг. Махан биеийн таашаалыг үргэлж эрэлхийлдэг чам шиг хулчгар хүнд зүрх сэтгэл байдаг уу, сүнс байдаг уу? Чи араатан биш гэж үү? Би хариуд нь юу ч нэхэлгүйгээр үнэн замыг чамд өгсөн, гэсэн ч чи үүнийг эрэлхийлдэггүй. Чи Бурханд итгэдэг хүмүүсийн нэг мөн гэж үү? Би жинхэнэ хүний амьдралыг чамд өгсөн, гэсэн ч чи үүнийг эрэлхийлдэггүй. Чи гахай, нохойноос өөрцгүй биш үү? Гахай хүний амьдралыг эрэлхийлдэггүй, цэвэрлүүлэхийг зорьдоггүй ба амьдрал гэж юу болохыг ойлгодоггүй. Өдөр болгон ходоодоо дүүртэл идчихээд зүгээр л унтаад өгдөг. Би чамд үнэн замыг өгсөн, гэсэн ч чи үүнийг олж аваагүй: Чи гар хоосон байгаа. Чи гахайных шиг амьдралаа үргэлжлүүлэхийг хүсэж байна уу? Тийм хүмүүс амьд

байхын ач холбогдол юу вэ? Амьдрал чинь жигшүүртэй агаад олиггүй, чи бохир заваан, садар самуун дунд амьдардаг, ямар ч зорилгыг эрэлхийлдэггүй; чиний амьдрал хамгийн олиггүй биш гэж үү? Чамд Бурханыг харах нүүр байгаа юу? Хэрвээ чи ийм маягаар үргэлжлүүлбэл юу ч олж авахгүй биш үү? Үнэн зам чамд өгөгдсөн, гэхдээ үүнийг эцэстээ олж авах уу, үгүй юу гэдэг чинь чиний хувийн эрэл хайгуулаас хамаарна. Бурхан бол зөвт Бурхан бөгөөд хүн эцэст нь хүртэл Түүнийг дагаж байгаа цагт Тэр хүнийг алагчлахгүй нь гарцаагүй, учир нь Тэр хамгийн зөвт гэж хүмүүс хэлдэг. Хэрвээ хүн Түүнийг эцэст нь хүртэл дагах юм бол Тэр хүнийг орхиж чадна гэж үү? Би бүх хүнд алагчлалгүй хандаж, бүх хүнийг зөвт зан чанараараа шүүдэг ч хүнд тавьдаг шаардлагуудад минь тохиромжтой нөхцөл байдаг бөгөөд хэн байхаас үл хамааран, Миний шаарддаг зүйлийг бүх хүн биелүүлэх ёстой. Чиний чадвар хэр болох нь, хэр удаан ийм чадвартай байсан чинь Надад хамаагүй; Миний замаар явж байгаа эсэхийг чинь, үнэнийг хайрлаж, үнэнээр цангаж байгаа эсэхийг чинь л Би анхаардаг. Хэрвээ чамд үнэн байхгүй, харин ч Миний нэрэнд ичгүүр авчирч, Миний замын дагуу үйлддэггүй бөгөөд ямар ч санаа зовнил, хайхрамжгүй зүгээр л дагадаг бол тэр үед Би ёрын муугийн чинь төлөө чамайг цохин унагаж, чамайг шийтгэнэ, тэр үед чи юу гэх вэ? Бурхан бол зөвт биш гэж чи хэлж чадах уу? Өнөөдөр, хэрвээ чи Миний хэлсэн үгийг мөрдсөн бол Миний сайшаадаг төрлийн хүн мөн. Бурханыг дагах явцдаа үргэлж зовж шаналсан, бэрхшээлийг үл тоомсорлон Түүнийг дагасан, сайн, муу бүх цаг үеийг Түүнтэй хуваалцсан гэж чи хэлдэг боловч Бурханы хэлсэн үгийг амьдран харуулаагүй; чи өдөр бүр Бурханы төлөө гүйж, Түүний төлөө өөрийгөө зарлагадахыг л хүсдэг ба утга учиртай амьдралыг амьдран харуулах талаар хэзээ ч бодож үзээгүй. Чи бас “Ямар ч тохиолдолд Бурхан бол зөвт гэдэгт би итгэдэг. Би Түүний төлөө зовсон, Түүний төлөө ийш тийш гүйсэн, өөрийгөө Түүнд зориулсан ба гавьяа хүртээгүй хэр нь шаргуу ажилласан; Тэр гарцаагүй намайг санаж байгаа” гэж хэлдэг. Бурхан зөвт гэдэг нь үнэн ч энэхүү зөвт байдал ямар ч хольцоор сэвтээгүй: Үүнд хүний ямар ч хүсэл байдаггүй ба махан бие юм уу хүний арилжаа наймаа холилддоггүй. Тэрслүү агаад эсэргүүцдэг бүхэн, Түүний замыг даган мөрддөггүй бүхэн шийтгүүлнэ; хэн ч уучлагдахгүй, хэн ч өршөөгдөхгүй! Зарим хүн: “Өнөөдөр би Таны төлөө гүйлээ; эцэстээ Та надад жаахан ерөөл өгч чадах уу?” гэдэг. Тэгэхэд Би чамаас “Чи Миний үгийг мөрдсөн үү?” гэж асууна. Чиний ярьдаг зөвт байдал арилжаа наймаанд үндэслэдэг. Би бол зөвт бөгөөд бүх хүнд алагчлалгүй ханддаг учраас л Намайг эцсээ хүртэл дагадаг хүмүүс гарцаагүй аврагдаж, Миний ерөөлийг хүртэнэ гэж чи боддог. “Намайг эцсээ хүртэл дагадаг хүмүүс гарцаагүй аврагдана” гэх Миний үгэнд далд утга бий: Намайг бүр эцэст нь хүртэл дагадаг хүмүүс бол Надаар бүрэн авхуулах хүмүүс юм, тэд бол Надаар байлдан дагуулагдсаныхаа дараа үнэнийг эрж хайж, төгс болгуулдаг хүмүүс юм. Чи ямар нөхцөлийг биелүүлсэн бэ? Чи ердөө Намайг эцэст нь хүртэл дагасан, гэхдээ өөр яасан гэж? Чи Миний үгийг мөрдсөн үү? Миний таван шаардлагаас

нэгийг биелүүлсэн ч үлдсэн дөрвийг нь биелүүлэх санаа зорилго чамд байдаггүй. Чи ердөө хамгийн энгийн, хамгийн амархан замыг олоод, азтай болно гэж найдсан хандлагаар л энэ замыг хөөсөн. Чам шиг тийм хүмүүст Миний зөвт зан чанар бол зөвхөн гэсгээлт, шүүлт, зөвт залхаан цээрлүүлэлт бөгөөд мууг үйлдэгч бүхний зөвт шийтгэл энэ юм; эцэст нь хүртэл дагасан ч гэсэн, Миний замаар алхдаггүй бүх хүн гарцаагүй шийтгүүлнэ. Энэ нь Бурханы зөвт байдал билээ. Энэхүү зөвт зан чанар хүний шийтгэлд илэрхийлэгдэх үед хүн цочирдож, Бурханыг дагах зуураа Түүний замаар алхаагүйдээ харамсана. “Тухайн үед Бурханыг дагах зуураа би бага зэрэг зовсон боловч Бурханы замаар алхаагүй. Энд ямар шалтаг байх билээ? Гэсгээгдэхээс өөр сонголт байхгүй!” Гэсэн ч оюун санаандаа хүн: “Ямартай ч би эцэст нь хүртэл дагасан, иймээс Та намайг гэсгээсэн ч гэсэн, тийм ч хатуу гэсгээлт байж таарахгүй, тэгээд энэ гэсгээлтийг тулгасныхаа дараа Та намайг хүссээр байх болно. Та зөвт бөгөөд надад үүрд тэгж хандахгүй гэдгийг би мэднэ. Эцсийн эцэст би устгагдах хүмүүстэй адилгүй; устгагдах хүмүүс хүнд гэсгээлт хүлээн авна, харин миний гэсгээлт хөнгөн байна” гэж боддог. Зөвт зан чанар чиний хэлдэг шиг биш. Өөрсдийн нүглийг улайхдаа сайн хүмүүстэй зөөлөн харьцдаг гэсэн зүйл байхгүй. Зөвт байдал бол ариун байдал, энэ нь хүний халдлагыг тэвчдэггүй зан чанар бөгөөд бохир заваан, өөрчлөгдөөгүй бүхэн бол Бурханы зэвүүцлийн бай юм. Бурханы зөвт зан чанар нь хууль биш, харин захиргааны зарлиг юм: Энэ нь хаанчлалын доторх захиргааны зарлиг бөгөөд үнэнийг эзэмшдэггүй, өөрчлөгдөөгүй хэний ч хувьд энэ захиргааны зарлиг нь зөвт шийтгэл, энд ямар ч аврал үгүй. Хүн болгон төрлийнхөө дагуу ангилагдах үед сайн нь шагнагдаж, муу нь шийтгүүлнэ. Энэ нь хүний хүрэх газар тодорхой болох үе; авралын ажил төгсгөл болж, хүнийг аврах ажил хийгдэхээ больж, мууг үйлддэг хүн нэг бүрд залхаан цээрлүүлэлт очих үе юм. Зарим хүн: “Бурхан Өөрийнх нь хажууд үргэлж байдаг хүн нэг бүрийг санадаг. Тэрээр бидний хэнийг ч мартахгүй. Бид гарцаагүй Бурханаар төгс болгуулна. Тэрээр доор байгаа хүмүүсийн хэнийг ч санахгүй, тэдний дундаас төгс болгуулах хүмүүс нь Бурхантай байнга уулздаг биднээс цөөхөн байх нь лавтай; бидний дундаас хэнийг ч Бурхан мартахгүй, бид бүгдээрээ Бурханаар хүлээн зөвшөөрөгдсөн ба Бурханаар төгс болгуулах нь гарцаагүй” гэж хэлдэг. Та нар бүгдээрээ ийм үзэлтэй байдаг. Энэ нь зөвт байдал мөн үү? Чи үнэнийг хэрэгжүүлсэн үү, үгүй юу? Чи үнэндээ иймэрхүү цуу яриа түгээдэг—чамд ямар ч ичгүүр сонжуур алга!

Өнөөдөр, зарим хүн Бурханаар ашиглуулахыг зорьдог боловч байлдан дагуулагдсаныхаа дараа шууд ашиглуулж чадахгүй. Өнөөдрийн ярьсан үгийн тухайд гэвэл, хэрвээ Бурхан хүмүүсийг ашиглах үед чи бас л тэдгээрийг биелүүлж чадахгүй байвал төгс болгуулаагүй байна. Өөрөөр хэлбэл, хүн төгс болгуулах цагийн төгсгөл ирэх нь хүн Бурханд таягдуулан хаягдах уу, эсвэл ашиглуулах уу гэдгийг тодорхойлно. Байлдан дагуулагдсан хүмүүс бол зүгээр л идэвхгүй байдал ба сөрөг байдлын үлгэр жишээ төдий юм; тэд бол үлгэр жишээ, загвар, гэхдээ

зөвхөн эсрэг талын товойлгогчоос цаашгүй. Хүний амь зан чанар өөрчлөгдөж, дотор гаднагүй өөрчлөлтөд хүрсэн үедээ л бүрэн төгс болгуулсан байх болно. Өнөөдөр чи байлдан дагуулагдах, эсвэл төгс болгуулахын алийг хүсдэг вэ? Чи алинд нь хүрэхийг хүсдэг вэ? Төгс болгуулах нөхцөлүүдийг чи биелүүлсэн үү? Чамд аль нөхцөл нь дутагдсаар байдаг вэ? Чи өөрийгөө хэрхэн зэвсэглэх ёстой вэ, мөн дутагдлуудаа хэрхэн нөхөх ёстой вэ? Чи хэрхэн төгс болгуулах замд орох ёстой вэ? Чи хэрхэн бүрэн дүүрэн захирагдах ёстой вэ? Чи төгс болгуулах хүсэлт тавьдаг, тэгвэл чи ариун байдлыг эрэлхийлдэг хүн мөн үү? Чи ариусгагдахын тулд гэсгээлт, шүүлт туулахаар эрэлхийлдэг хүн мөн үү? Чи цэвэрлэгдэхээр эрэлхийлдэг тул гэсгээлт, шүүлтийг хүлээн авахад бэлэн байна уу? Чи Бурханыг мэдье гэх хүсэлт тавьдаг, гэвч Түүний гэсгээлт, шүүлтийн талаарх мэдлэг чамд байгаа юу? Өнөөдөр, чам дээр Түүний хийдэг ихэнх ажил бол гэсгээлт, шүүлт; чам дээр хийгдэж байгаа энэхүү ажлын тухай чиний мэдлэг юу вэ? Чиний туулсан гэсгээлт, шүүлт чамайг цэвэрлэсэн үү? Энэ нь чамайг өөрчилсөн үү? Чамд ямар нэг үр нөлөө үзүүлсэн үү? Чи өнөөдрийн маш их ажил—хараал, шүүлт ба илчлэлтээс залхаж байна уу—эсвэл эдгээр зүйл чамд асар их ашиг тустай гэж санагдаж байна уу? Чи Бурханыг хайрладаг, гэхдээ юунаас болж Бурханыг хайрладаг вэ? Жаахан нигүүлсэл хүлээн авсан учраас л Бурханыг хайрладаг уу? Эсвэл амар амгалан, баяр баясгаланг олж авсныхаа дараа Бурханыг хайрладаг уу? Эсвэл чи гэсгээлт, шүүлтээр нь цэвэрлэгдсэнийхээ дараа Бурханыг хайрладаг уу? Яг юу чамайг Бурханыг хайрлахад хүргэдэг вэ? Төгс болгуулахын тулд Петр ямар нөхцөлүүдийг биелүүлсэн бэ? Түүнийг төгс болгуулсны дараа гол чухал илэрхийлэл нь юу байсан бэ? Тэр Эзэн Есүсийг үгүйлэн санаж байсан учраас Түүнийг хайрласан уу, эсвэл Түүнийг харж чадаагүй учраас уу, эсвэл тэр зэмлүүлсэн учраас уу? Эсвэл тэр зовлон шаналлыг хүлээн авч, өөрийнхөө бохир заваан, дуулгаваргүй байдлыг мэдэж авч, Эзэний ариун байдлыг мэдэж авсан учраас Эзэн Есүсийг бүр ч их хайрласан уу? Бурханыг гэх түүний хайр Бурханы гэсгээлт, шүүлтээс болж илүү цэвэр ариун болсон уу, эсвэл өөр зүйлээс болсон уу? Аль нь вэ? Чи Бурханы нигүүлслээс болж, мөн өнөөдөр Тэр чамд ялимгүй жаахан ерөөл өгснөөс болж Бурханыг хайрладаг. Энэ жинхэнэ хайр мөн үү? Чи Бурханыг хэрхэн хайрлах ёстой вэ? Түүний гэсгээлт, шүүлтийг хүлээн авч, зөвт зан чанарыг нь харсныхаа дараа Түүнийг үнэхээр хайрлаж чаддаг болж, улмаар бүрэн үнэмшиж, Түүнийг мэддэг болох ёстой юу? Петртэй адилаар, Бурханыг хангалттай хайрлаж чаддаггүй гэж чи хэлж чадах уу? Чиний эрэлхийлдэг зүйл чинь гэсгээлт, шүүлтийн дараа байлдан дагуулагдах явдал уу, эсвэл гэсгээлт, шүүлтийн дараа цэвэрлэгдэж, хамгаалагдаж, халамжлуулах явдал уу? Эдгээрийн алийг чи эрэлхийлдэг вэ? Чиний амьдрал утга учиртай юу, эсвэл ямар ч утгагүй, үнэ цэнгүй юу? Чи махан биеийг хүсдэг үү, эсвэл үнэнийг хүсдэг үү? Чи шүүлтийг хүсэж байна уу, эсвэл тав тухыг уу? Бурханы ажлаас маш ихийг туулж, Бурханы ариун байдал ба зөвт байдлыг харсан болохоор чи хэрхэн эрэлхийлэх ёстой вэ? Чи энэ замаар хэрхэн алхах ёстой вэ? Чи Бурханыг

гэх хайраа хэрхэн хэрэгжүүлэх ёстой вэ? Бурханы гэсгээлт, шүүлт чамд ямар нэг үр нөлөө үзүүлсэн үү? Бурханы гэсгээлт, шүүлтийн талаар мэдлэгтэй юу, үгүй юу гэдэг чинь юуг амьдран харуулж байгаагаас чинь, мөн Бурханыг ямар хэмжээнд хайрладгаас чинь хамаардаг! Ам чинь Бурханд хайртай гэж хэлдэг ч амьдран харуулдаг зүйл чинь хуучин, завхарсан зан чанар юм; чамд Бурханаас айх айдас огт байдаггүй, мөс чанар бүр ч байдаггүй. Тийм хүмүүс Бурханыг хайрладаг уу? Тийм хүмүүс Бурханд үнэнч үү? Тэд Бурханы гэсгээлт, шүүлтийг хүлээн авдаг хүмүүс мөн үү? Чи Бурханыг хайрладаг ба Түүнд итгэдэг гэж хэлдэг ч өөрийн үзлийг хаяж чаддаггүй. Чиний ажилд, оролтод, чиний хэлдэг үгэнд, чиний амьдралд Бурханыг гэх хайрын ямар ч илрэл байдаггүй ба Бурханыг хүндлэх хүндлэл байдаггүй. Энэ нь гэсгээлт, шүүлтийг хүртсэн хүн мөн үү? Ийм хүн Петр шиг байж чадах уу? Петр шиг хүмүүс зөвхөн мэдлэгтэй байдаг ч амьдран харуулдаггүй юм гэж үү? Өнөөдөр, хүнээс жинхэнэ хүний амьдралыг амьдран харуулахыг шаарддаг нөхцөл нь юу вэ? Петрийн залбирал нь түүний амнаас гарсан үгээс цаашгүй байсан уу? Тэдгээр нь түүний зүрх сэтгэлийн гүнээс гарсан үг байсан бус уу? Петр зөвхөн залбираад, үнэнийг хэрэгжүүлдэггүй байсан уу? Чиний эрэл хайгуул хэний төлөө байдаг вэ? Бурханы гэсгээлт, шүүлтийн үеэр чи өөрийгөө хэрхэн хамгаалуулж, цэвэрлүүлэх ёстой вэ? Бурханы гэсгээлт, шүүлт хүнд ямар ч ашиг тусгүй юу? Бүх шүүлт нь шийтгэл мөн үү? Зөвхөн амар амгалан, баяр хөөр, материаллаг ерөөл, түр зуурын тав тух л хүний аминд ашиг тустай юм гэж үү? Хэрвээ хүн шүүлтийн амьдралгүйгээр таатай, тухтай орчинд амьдардаг бол цэвэрлэгдэж чадах уу? Хэрвээ хүн өөрчлөгдөж, цэвэрлэгдэхийг хүсдэг бол төгс болгуулахыг хэрхэн хүлээн авах ёстой вэ? Чи өнөөдөр аль замыг сонгох ёстой вэ?

ТА НАР АЖЛЫГ ОЙЛГОХ ЁСТОЙ— ТӨӨРӨЛДСӨН БАЙДЛААР БҮҮ ДАГА!

Одоо үед төөрөлдсөн байдлаар итгэдэг олон хүн бий. Та нар хэт их сониуч зантай, хэрээс хэтэрсэн ерөөгдөх хүсэлтэй, харин та нарын амийг эрж хайх тэмүүлэл тун өчүүхэн. Өнөө үеийн хүмүүс Есүст урам зориг дүүрэн итгэдэг. Есүс тэднийг тэнгэр дэх гэр лүү буцаан авч явах болохоор итгэхгүй байж яахан чадах билээ? Зарим хүн бүхий л амьдралынхаа туршид итгэгч байдаг; дөч, тавин жил итгэснийхээ дараа ч тэд Библийг уншихаас хэзээ ч залхдаггүй. Учир нь, юу ч тохиолдсон бай хамаагүй, итгэж л байгаа цагт тэнгэр лүү очно гэж тэд боддог[a]. Та нар Бурханыг энэ замаар хэдхэн жил л дагасан атлаа аль хэдийн тээнэгэлзчихжээ; та нарын ерөөл олж авах хүсэл хэтэрхий хүчтэй учир тэвчээр чинь алдарчээ. Ерөөл олж авах хүсэл болон сониуч зандаа захирагдаад л та нар энэ үнэн замаар алхдаг.

[a] Эх бичвэрт “тэд боддог” гэх хэллэг байдаггүй.

Ажлын энэ үе шатны талаарх ойлголт та нарт тийм ч их байхгүй. Өнөөдөр Миний хэлж байгаа зүйлийн ихэнх нь Есүст итгэдэг хүмүүст хандаагүй байдаг, тэдний үзлийг сөрөх гэж ч үүнийг хэлж байгаа юм биш. Үнэндээ, ил болж байгаа эдгээр үзэл нь та нарын дотор оршдог яг тэр үзлүүд юм, учир нь яагаад Библийг хойш тавьж ирснийг, яагаад Би Еховагийн ажил хуучирсан, Есүсийн ажил хуучирсан гэж хэлдгийг та нар ойлгодоггүй. Үнэндээ та нарт дотроо тээж, ил гаргаж хэлдэггүй олон үзэл байдаг, түүнчлэн зүрх сэтгэлийнхээ гүнд олон санаа бодлыг нууж явдаг бөгөөд бас та нар зүгээр л олныг дагадаг. Та нар үнэхээр өөрсдийгөө олон үзэл өвөрлөдөггүй гэж бодож байна уу? Та нар зүгээр л тэдгээрийн талаар ярихгүй байгаа төдий! Үнэндээ та нар Бурханыг зөвхөн нэр төдий дагадаг, ердөө ч үнэн замыг эрж хайж ирээгүй бөгөөд амь олж авах бодолтой ч ирээгүй юм. Та нарын хандлага бол зөвхөн юу тохиолдохыг харахыг хүссэн хүний хандлага. Хуучин олон үзлээ орхиогүй учраас өөрийгөө бүрэн зориулж чадсан хүн та нарын дунд нэг ч байхгүй. Энэ хүртэл ирчхээд та нар одоо ч гэсэн хувь заяаныхаа талаар санаа зовж, өдөр шөнөгүй бодол болж байдаг ба үүнийгээ больж огт чаддаггүй. Би фарисайчуудын талаар ярихдаа шашны “ахмадууд”-ын талаар ярьдаг гэж чи бодож байна уу? Та нар өнөө үеийн хамгийн боловсронгуй фарисайчуудын төлөөлөгчид биш гэж үү? Намайг Библитэй харьцуулдаг хүмүүсийг дурдахдаа Би зөвхөн шашны хүрээний Библийн мэргэжилтнүүдийг хэлж байна гэж чи бодож байна уу? Бурханыг дахин нэгэнтээ загалмайд хадаж буй хүмүүсийн тухай ярихдаа Би шашны хүрээний удирдагчдын тухай ярьж байна гэж чи бодож байна уу? Та нар энэ дүрд тоглох хамгийн сайн жүжигчид биш гэж үү? Хүмүүсийн үзлийн эсрэг тэмцэхийн тулд Миний хэлдэг бүх үг ердөө л шашны пасторууд болон ахлагчдыг дооглож байгаа гэж чи бодож байна уу? Та нар бас энэ бүх зүйлд оролцоогүй гэж үү? Өөрсдийгөө хэдхэн үзэл тээдэг гэж чи бодож байна уу? Ердөө л та нар бүгд одоо маш ухаалаг байж сурсан юм. Та нар ойлгодоггүй зүйлсийнхээ талаар ярьдаггүй, тэр талаарх мэдрэмжээ ил гаргадаггүй ч дотор чинь хүндлэл, дуулгавартай байх сэтгэл ердөө ч байдаггүй. Та нарын харж байгаачлан судлах, ажиглах болон хүлээх нь та нарын өнөөдрийн хамгийн шилдэг хэрэгжүүлэлтийн арга зам юм. Та нар хэтэрхий ухаалаг байж сурсан. Гэвч энэ бол нэг төрлийн сэтгэл зүйн заль мэх гэдгийг та нар ухаарч байна уу? Та нарын нэг хормын ухаалаг байдал мөнхийн гэсгээлтээс зугтахад чинь тусална гэж та нар бодож байна уу? Та нар үнэхээр “ухаалаг” байж сурсан! Түүнчлэн, зарим хүн Надаас: “Хэзээ нэг өдөр шашны хүрээний хүмүүс надаас ‘Яагаад та нарын Бурхан ганц ч гайхамшиг үзүүлээгүй юм бэ?’ гэж асуувал би юу гэж тайлбарлах ёстой вэ?” гэх мэтийн зүйл асуудаг. Өнөө цагт зөвхөн шашны хүрээний хүмүүс ингэж асуудаггүй. Харин ч чи өнөөдрийн ажлыг ойлгодоггүй бөгөөд хэтэрхий олон үзэл дор амьдардаг. Шашны албан тушаалтнуудыг дурдахдаа Би хэнийг хэлдгийг чи одоо ч мэдэхгүй гэж үү? Би хэнд Библийг тайлбарлаж байгааг чи мэдэхгүй гэж үү? Бурханы ажлын гурван үе шатыг тайлбарлахдаа Би хэнд зориулж ярьж байгааг чи мэдэхгүй гэж үү? Би эдгээр

зүйлийг хэлээгүй байсан бол та нар тийм амархан үнэмших байсан уу? Та нар тийм амархан толгой бөхийх байсан уу? Хуучин үзлээ тийм амархан хойш нь тавих байсан уу? Ялангуяа хэзээ ч хэнд ч захирагдаж байгаагүй тэр “жинхэнэ эрчүүд” тийм амархан захирагдах байсан уу? Та нар доод түвшний хүн чанартай, маш дорд хэв чанартай, хөгжил дорой уураг тархитай бөгөөд Бурханд итгэсэн замнал чинь тийм ч урт биш мөртөө чухамдаа нэлээд их үзэлтэй бөгөөд хэнд ч амархан захирагдаад байдаггүй төрөлх уг чанартай гэдгийг чинь Би мэднэ. Өнөөдөр гэхдээ та нар хүчинд автаж, аргагүй болсон учраас захирагдах чадвартай байдаг; та нар бол ур чадвараа чөлөөтэй ашиглах чадваргүй байгаа төмөр торон дахь барс. Далавчтай байсан ч та нарт нисэхэд хэцүү байх болно. Хэдийгээр ерөөл хүртээгүй боловч та нар дагахад бэлэн байсаар байдаг. Гэхдээ энэ нь та нарын “сайн хүний” араншин биш, харин ч та нар бүрэн уналтад орж, аргаа барж байна гэсэн үг юм. Энэ бүх ажил та нарыг цохин унагажээ. Хэрвээ та нар ямар нэгэн зүйлд хүрч чадах байсан бол өнөөдрийнх шигээ дуулгавартай байхгүй байх байсан, учир нь өмнө нь та нар бүгдээрээ зэлүүд талын зэрлэг хулан байсан юм. Тиймээс өнөөдөр хэлж байгаа зүйл нь дан ганц янз бүрийн шашин, урсгалын хүмүүс рүү чиглээгүй, бас зөвхөн тэдний үзэлтэй зөрчилдөх зорилготой ч юм биш; харин та нарын үзлийн эсрэг тэмцэхийн төлөө байдаг юм.

Зөвт байдлын шүүлт эхэллээ. Бурхан бас л хүмүүсийн төлөөх нүглийн тахил болох болов уу? Тэр тэдний төлөө дахин нэгэнтээ агуу эмчийн үүрэг гүйцэтгэх болов уу? Бурханд үүнээс илүү их эрх мэдэл байхгүй гэж үү? Бүлэг хүмүүсийг аль хэдийн бүрэн төгс болгож сэнтийн өмнө аваачсан; гэсэн ч Тэр чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээх болов уу? Энэ чинь хэтэрхий хуучинсаг биш гэж үү? Энэ байдлаар үргэлжилбэл гэрчлэл хийх боломжтой байх болов уу? Загалмайд нэгэнтээ хадагдлаа гээд Бурхан үүрд цовдлогдсон болох уу? Тэр чөтгөрүүдийг нэг удаа хөөн зайлуулчхаад үүрд хөөн зайлуулсаар байж болох уу? Энэ чинь доромжилсон хэрэг биш гэж үү? Зөвхөн ажлын энэ үе шат өмнөхөөсөө сүрлэг байж гэмээ нь л эрин үе урагшлан хөгжих бөгөөд тэр цагт эцсийн өдрүүд хаяанд ирж, энэ эрин үе дуусах цаг ирэх болно. Тиймээс, үнэнийг эрэлхийлдэг хүмүүс үзэгдлүүдийг ойлгож мэдэхэд анхаарлаа хандуулах ёстой; энэ бол суурь нь юм. Үзэгдлийн талаар та нартай нөхөрлөх болгондоо Би зарим хүмүүсийн зовхи нь унжиж, сонсох хүсэлгүй зүүрмэглэхийг дандаа хардаг. Бусад нь: “Чи яагаад сонсохгүй байгаа юм бэ?” гэж асуух үед тэд: “Энэ миний аминд, эсвэл бодит байдал руу ороход минь туслахгүй. Бидний хүсдэг зүйл бол хэрэгжүүлэлтийн зам” гэж хэлдэг. Би хэрэгжүүлэлтийн замаас илүү ажлын тухай ярих болгонд тэд: “Таныг ажлын тухай яринуут би унтаж эхэлдэг” гэдэг. Намайг хэрэгжүүлэлтийн тухай ярьж эхлэнгүүт тэд тэмдэглэж эхэлдэг бөгөөд ажлын талаар эргээд тайлбарлахаар буцаад сонсохоо больдог. Та нар одоо юугаар зэвсэглэх ёстойгоо мэдэх үү? Үүний нэг талд нь ажлын тухай үзэгдэл, нөгөө талд нь чиний хэрэгжүүлэлт багтана. Чи хоёр талыг хоёулыг нь ойлгож авах ёстой. Хэрвээ аминд дэвшил гаргах эрэл хайгуулд чинь

үзэгдэл байхгүй бол чи суурьгүй байх болно. Хэрвээ чамд өчүүхэн ч үзэгдэл байхгүй, зөвхөн хэрэгжүүлэлтийн зам байгаа бөгөөд удирдлагын төлөвлөгөөний ерөнхий ажлын талаар ямар ч ойлголт байдаггүй бол чи хэнд ч хэрэггүй хүн юм. Үзэгдэлтэй холбоотой үнэнийг чи ойлгох ёстой бөгөөд хэрэгжүүлэлттэй холбоотой үнэний тухайд гэвэл чи тэдгээрийг ойлгосныхоо дараа хэрэгжүүлэх зохистой замыг олох хэрэгтэй; чи үгийн дагуу хэрэгжүүлж, өөрийнхөө нөхцөл байдлын дагуу орох хэрэгтэй. Үзэгдлүүд бол үндэс суурь бөгөөд хэрэв чи энэхүү бодит үнэнд ямар ч анхаарал хандуулдаггүй бол эцсийг нь хүртэл дагаж чадахгүй; ийм маягаар туршлагажих нь чамайг нэг бол замаа алдахад, эс бөгөөс унаж бүтэлгүйтэхэд хүргэнэ. Чи яагаад ч амжилтад хүрэхгүй! Агуу үзэгдлийг үндэс сууриа болгоогүй хүмүүс зөвхөн бүтэлгүйтнэ, тэд амжилтад хүрч чадахгүй. Чи бат зогсож чадахгүй! Бурханд итгэнэ гэдэг юу болохыг чи мэдэх үү? Бурханыг дагана гэдэг нь юу гэсэн үг болохыг мэдэх үү? Үзэгдэлгүйгээр чи ямар замаар алхах вэ? Өнөөдрийн ажилд чамд ямар ч үзэгдэл байхгүй бол чи огтхон ч бүрэн төгс болгуулж чадахгүй. Чи хэнд итгэдэг вэ? Чи яагаад Түүнд итгэдэг вэ? Яагаад Түүнийг дагадаг вэ? Чи өөрийнхөө итгэлийг ямар нэг тоглоом гэж боддог уу? Өөрийнхөө аминд нэг төрлийн тоглоом мэт ханддаг уу? Өнөөдрийн Бурхан бол хамгийн агуу үзэгдэл юм. Түүний тухай хэр ихийг чи мэддэг вэ? Түүнээс хэр ихийг харсан бэ? Өнөөдрийн Бурханыг харсан болохоор Бурханд итгэх итгэлийн чинь суурь бат бөх байдаг уу? Энэ будилуу янзаараа дагаж л байвал аврал хүртэнэ гэж чи бодож байна уу? Чи булингартай уснаас загас барьж чадна гэж бодож байна уу? Энэ тийм энгийн гэж үү? Өнөөдрийн Бурханы айлддаг үгийн талаарх хэр олон үзлээ чи хаясан бэ? Чамд өнөөдрийн Бурханы талаарх үзэгдэл байгаа юу? Өнөөдрийн Бурханы талаарх ойлголт чинь хаана оршдог вэ? Зүгээр л дагаснаараа, эсвэл зүгээр л харснаараа Түүнийг[б] олж авч чадна, хэн ч чамайг зайлуулж чадахгүй гэж чи үргэлж боддог. Бурханыг дагах тийм амархан гэж бүү бод. Гол нь чи Түүнийг мэдэж, Түүний ажлыг мэдэх ёстой бөгөөд Түүний төлөө зовлон бэрхшээл туулж, өөрийнхөө амийг золиосолж, Түүгээр төгс болгуулах хүсэлтэй байх ёстой. Энэ бол чамд байх ёстой үзэгдэл юм. Нигүүлсэл эдлэх тухай үргэлж боддог байж болохгүй. Бурхан зүгээр л хүмүүсийг баясгаж, тэдэнд нигүүлсэл хайрлахын төлөө энд байгаа гэж бүү бод. Чи эндүүрч байна! Хүн Бурханыг дагахын тулд амьдралаараа дэнчин тавьж чадахгүй, мөн энэ ертөнцийн өмч хөрөнгөө орхиж чадахгүй бол эцсээ хүртэл Түүнийг дагасаар байж чадахгүй нь лавтай! Чи өөрийгөө үзэгдэлд суурилах ёстой. Хэрвээ нэг өдөр гай гамшиг чамд тохиолдвол чи юу хийх ёстой вэ? Чи Түүнийг дагасаар байж чадах уу? Эцсийг нь хүртэл дагаж чадах эсэхээ хөнгөмсгөөр бүү хэл. Чи эхлээд нүдээ том нээгээд одоо яг ямар цаг болохыг харсан нь дээр юм. Хэдий та нар одоо сүмийн багана шиг байж болох боловч энэ баганууд өт хорхойд идэгдэж, сүмийг нурж унахад хүргэх цаг ирэх болно, учир нь одоогоор та нарт маш олон үзэгдэл

[б] Эх бичвэрт “Түүнийг” гэдэг үг байдаггүй.

дутагддаг. Та нар зөвхөн өөрсдийнхөө бяцхан ертөнцөд анхаарал хандуулдаг бөгөөд эрж хайх хамгийн найдвартай бөгөөд зүй зохистой арга зам юу болохыг мэддэггүй. Та нар өнөөдрийн ажлын үзэгдлийг анхаардаггүй бөгөөд эдгээр зүйлийг зүрх сэтгэлдээ хадгалдаггүй. Нэг л өдөр Бурхан тань та нарыг огт танил биш газарт аваачих болно гэдгийг та нар бодож үзсэн үү? Би та нараас бүх зүйлийг чинь нэг өдөр булааж авахад та нарт юу болохыг төсөөлж чадах уу? Тэр өдөр та нарын эрч хүч одоогийнх шигээ байх уу? Та нарын итгэл дахин гарч ирэх үү? Бурханыг дагахдаа “Бурхан” хэмээх энэхүү хамгийн агуу үзэгдлийг мэдэх ёстой. Энэ бол хамгийн чухал асуудал. Бас ариун болохын тулд энэ хорвоогийн хүмүүсээс харьцаагаа таслалаа гээд Бурханы гэр бүл болчихно гэж бүү бод. Өнөө үед бүтээлийн дунд Бурхан Өөрөө ажиллаж байгаа; Бурхан кампанит ажил хийхээр биш, Өөрийн ажлыг хийхээр хүмүүсийн дунд ирсэн. Өнөөдрийн ажил бол тэнгэр дэх махбод болсон Бурханы ажил гэдгийг мэдэж чадах цөөхөн хүн ч та нарын дунд байдаггүй. Энэ бол та нарыг гайхалтай авьяастай хүмүүс болгох явдал биш; энэ бол хүний амьдралын утга учрыг мэдэж, хүмүүний хүрэх газрыг мэдэн, Бурханыг болон Түүний бүрэн дүүрэн байдлыг мэдэхэд та нарт туслахын төлөө юм. Чи бол Бүтээгчийн гар дахь бүтээл гэдгээ мэдэх ёстой. Чи юуг ойлгох ёстой, юуг хийх ёстой, Бурханыг хэрхэн дагах ёстой зэрэг нь чиний ухаж ойлгох ёстой үнэн биш гэж үү? Энэ чиний харах ёстой үзэгдлүүд биш гэж үү?

Хүмүүс үзэгдэлтэй болмогцоо суурьтай болдог. Энэхүү суурин дээр үндэслэн хэрэгжүүлэх үед, ороход хамаагүй илүү амархан байх болно. Тийм болохоор орох суурьтай болох үед чиний болгоомжлол байхгүй болж, чамд ороход маш амархан болох болно. Үзэгдлийг ойлгох, Бурханы ажлыг мэдэх гэдэг энэ тал нь амин чухал юм; үүнийг та нар нөөцдөө байлгах ёстой. Хэрвээ чи үнэний энэ талаар зэвсэглээгүй, харин зөвхөн хэрэгжүүлэлтийн замын талаар л ярьж мэддэг бол энэ чиний асар том дутагдал болно. Та нарын олонх нь үнэний энэ талыг чухалчилдаггүйг Би олж мэдсэн бөгөөд үүнийг сонсох үедээ зөвхөн үг болон хоосон сургаалыг сонсож байгаа мэт байдаг. Нэг л өдөр чи алдах болно. Өнөө үед чиний сайн ойлгодоггүй, хүлээж авдаггүй зарим нэг айлдвар байдаг; энэ тохиолдолд чи тэвчээртэйгээр эрж хайх ёстой бөгөөд ойлгох өдөр чамд ирнэ. Өөрийгөө улам их үзэгдлээр аажмаар зэвсэглэ. Чи ердөө цөөхөн сүнслэг сургаалыг ойлгодог байсан ч гэсэн энэ нь үзэгдэлд анхаарал хандуулахгүй, мөн юу ч ойлгохгүй байснаас л дээр. Энэ бүхэн нь чиний оролтод нэмэртэй бөгөөд эргэлзээг чинь арилгана. Үзлээр дүүрсэн байснаас энэ нь дээр. Эдгээр үзэгдлийг суурь болговол чи хавгүй дээр байх болно. Чамд ямар ч болгоомжлол байхгүй болж, зоригтой бөгөөд итгэлтэй орж чадна. Үргэлж төөрөлдөж, эргэлзсэн байдлаар Бурханыг дагах ямар хэрэгтэй юм бэ? Энэ чинь чихээ бөглөөд хонх хулгайлж байгаатай адил биш гэж үү? Хаанчлалд омог бардам алхаж орвол хэчнээн сайхан! Яагаад болгоомжлолоор дүүрэн байна гэж? Энэ бол гагцхүү өөрийгөө жинхэнэ тамд оруулж байгаа хэрэг биш гэж үү? Еховагийн ажлын тухай, Есүсийн ажлын тухай, ажлын энэ үе шатны тухай

ойлголттой болмогцоо чи суурьтай болох болно. Одоохондоо чи үүнийг тун энгийн гэж төсөөлж магадгүй. Зарим хүн “Цаг нь ирж, Ариун Сүнс агуу ажлыг эхлүүлэх үед би энэ бүх зүйлсийн талаар ярьж чаддаг болно. Яг одоо би үнэхээр ойлгохгүй байгаа нь үнэндээ Ариун Сүнс намайг сайн гэгээрүүлээгүйгээс болж байгаа юм” гэдэг. Энэ тийм ч амархан биш. Чи үнэнийг[в] одоо хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа бол цаг нь ирэхэд үүнийг чадварлагаар ашиглана гэсэн үг биш. Тийм байх албагүй! Чи одоо өөрийгөө маш сайн зэвсэглэсэн бөгөөд тэр шашны хүмүүс болон шилдэг онолчдод хариулт өгч, тэднийг няцаахад ч чамд асуудалгүй байх болно гэж боддог. Чи үнэхээр тэгж чадах уу? Ердөө л тийм өнгөцхөн туршлагатайгаар чи ямар ойлголтын тухай ярьж чадах юм бэ? Үнэнээр зэвсэглэх, үнэний тулаанд тулалдах, Бурханы нэрээр гэрчлэл хийх гэдэг нь—Бурхан ажиллаж байгаа цагт бүх зүйл биелэх болно хэмээн чиний боддог шиг биш юм. Тэр үед магадгүй зарим асуулт чамайг мухардуулж, тэгээд чи цочирдон мэгдэнэ. Чи ажлын энэ үе шатны талаар тодорхой ойлголттой эсэх, мөн чи үнэндээ хэр ихийг мэддэг вэ гэдэг нь гол юм. Хэрвээ дайсны хүчийг ялан дийлж, шашны хүчнүүдийг ялж чадахгүй бол чи ямар ч хэрэггүй хүн болохгүй гэж үү? Хэрвээ чи өнөөдрийн ажлыг мэдэрч, нүдээрээ харж, чихээрээ сонссон боловч эцэстээ гэрчлэл хийж чадахгүй бол чамд цааш амьдрах нүүр үлдэнэ гэж үү? Чи хэнтэй нүүр тулгарч чадах байсан бэ? Тийм хялбар байна гэж одоо бүү төсөөл. Хожмын ажил чиний төсөөлж байгаа шиг хялбар байхгүй; Үнэний дайнд тулалдана гэдэг тийм амархан, тийм энгийн биш. Яг одоо чи зэвсэглэх хэрэгтэй; хэрвээ одоо үнэнээр зэвсэглэхгүй бол цаг нь ирж, Ариун Сүнс ер бусын байдлаар ажиллахаа болих үед чи юу хийхээ мэдэхгүй.

ЧИ ЗАМЫН СҮҮЛЧИЙН ХЭСЭГТ ЯАЖ АЛХАХ ЁСТОЙ ВЭ?

Чи одоо замын сүүлчийн хэсэгт ирсэн ба энэ бол замын амин чухал хэсэг юм. Магадгүй чи ихээхэн зовлон амсаж, их ажил хийж, олон замаар аялж, олон номлол сонссон байх; одоо байгаа газартаа ирэхэд амар байгаагүй биз. Хэрэв чи одоо нүүрлэж буй зовлонг тэсвэрлэж чадахгүй, хуучин шигээ үргэлжлүүлсээр байвал төгс болгуулж чадахгүй. Эдгээр үг чамайг айлгахаар зорьдоггүй—тэдгээр нь баримт юм. Петр Бурханы олон ажлыг туулсныхаа дараа зарим зүйлийг гүнзгий ойлгож, бас ихээхэн ялган таних чадвартай болсон. Тэрээр үйлчлэлийн зарчмын талаар олон зүйлийг ойлгож авсан ба хожим нь Есүсийн даалгасан зүйлд өөрийгөө бүрэн зориулж чадсан юм. Түүний хүлээн авсан асар их цэвэршүүлэлт нь ихэвчлэн, өөрийнхөө хийсэн зүйлийн төлөө Бурханд маш их өртэй мэт, мөн хэзээ ч буцаан төлж чадахгүй мэт түүнд санагдаж байснаас болсон билээ. Түүнчлэн, хүн маш их завхарсан гэдгийг Петр танин мэдсэн бөгөөд энэ нь мөс чанартаа буруугаа

[в] Эх бичвэрт “үнэнийг” гэх хэллэг байдаггүй.

мэдрэхэд хүргэжээ. Есүс Петрт олон зүйл хэлсэн боловч тэдгээрийг хэлж байх үед тэрээр бага зэрэг л ойлгох чадвартай байсан бөгөөд заримдаа эсэргүүцэл, тэрслүү байдал өвөрлөсөөр байлаа. Есүсийг загалмайд цовдлогдсоны дараа л тэр эцэст нь бага зэрэг сэхээрч, өөрийгөө хүчтэй зэмлэх сэтгэл түүнд төрсөн юм. Эцэстээ энэ нь, буруу санаа бодолтой байх нь хүлээн зөвшөөрөхийн аргагүй мэт санагдах хэмжээнд хүрчээ. Тэрээр өөрийн байр байдлыг тун сайн мэддэг, бас Эзэний ариун байдлыг сайн мэддэг байв. Үүний үр дүнд Эзэнийг хайрлах сэтгэл нь улам бүр нэмэгдэж, тэр өөрийн аминд илүү их төвлөрөх болжээ. Үүнээс болоод тэр асар их зовлон бэрхшээл туулсан ба заримдаа хүндээр өвчилсөн мэт, заримдаа бүр үхсэн мэт санагддаг байсан ч ийм маягаар олон удаа цэвэршүүлэгдсэний дараа өөрийгөө илүү их ойлгож авч, Эзэнийг үнэхээр хайрладаг болсон юм. Түүний бүхий л амьдрал цэвэршүүлэлт дунд өнгөрсөн, үүнээс ч илүүгээр гэсгээлт дунд өнгөрсөн гэж хэлж болно. Түүний туршлага өөр ямар ч хүнийхээс өөр байсан бөгөөд түүний хайр төгс болгуулаагүй хэний ч хайраас давж гарсан. Түүнийг үлгэр жишээ болгон сонгосны учир нь тэрээр амьдралынхаа хугацаанд хамгийн их зовлон шаналал амссан бөгөөд түүний туршлага хамгийн амжилттай байв. Хэрэв та нар замын сүүлчийн хэсэгт үнэхээр яг Петр шиг алхаж чадвал та нарын ерөөлийг булаан авч чадах бүтээгдсэн зүйл нэгээхэн ч үгүй.

Петр мөс чанартай хүн байсан боловч тийм хүн чанартай байсан ч гэсэн, Есүсийг анх дагаж эхлэх үедээ олон эсэргүү, тэрслүү бодол санаатай байсан нь гарцаагүй. Гэвч Есүсийг дагаж байх үедээ тэрээр эдгээр зүйлийг нухацтай авч үзэлгүй, хүмүүс ийм л байх ёстой гэж боддог байв. Иймээс тэр эхэндээ ямар ч зэмлэлийг мэдрээгүй, харьцалт ч туулаагүй. Есүс Петрийн хариу үйлдлийг ноцтойгоор авч үзээгүй, анхаарал хандуулаа ч үгүй, харин хийх ёстой ажлаа л үргэлжлүүлсэн. Тэрээр Петр болон бусдаас нь хэзээ ч өө хайгаагүй. “Тэд ийм санаа бодолтой байсныг Есүс мэдээгүй байж болно гэж үү?” хэмээн чи хэлж магад. Ердөө ч үгүй! Учир нь Тэр Петрийг үнэхээр ойлгосон—үнэндээ асар их ойлгож байсан учраас Есүс түүний эсрэг ямар ч арга хэмжээ аваагүй гэж хэлж болно. Тэр хүн төрөлхтнийг үзэн ядсан мөртөө бас өрөвдсөн. Одоо та нарын дунд Паул шиг эсэргүүцдэг, мөн тухайн үед Петр Эзэн Есүст хандаж байсан шиг олон үзэл өвөрлөдөг хүмүүс олон байдаг бус уу? Би чамд хэлье, гурав дахь мэдрэхүйдээ хэт их итгэхгүй байсан чинь дээр, чиний мэдрэхүй найдваргүй бөгөөд аль эрт Сатаны завхралаар бүрэн дүүрэн сүйтгэгдсэн. Чиний мэдрэхүй төгс, өө сэвгүй гэж чи бодож байна уу? Паул Эзэн Есүсийг олонтоо эсэргүүцсэн боловч Есүс хариу үйлдэл үзүүлээгүй. Есүс өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж чаддаг байсан атлаа Паулын доторх “чөтгөр”-ийг зайлуулж чадаагүй байж болох уу? Паул Есүсийн шавь нарыг дур зоргоороо үргэлжлүүлэн баривчилж байхад, яагаад дахин амилж, тэнгэр өөд гарсныхаа дараа л Есүс эцэст нь Дамаск орох замд нь түүнд үзэгдэж, түүнийг цохисон юм бэ? Эзэн Есүс дэндүү удаан хариу үйлдэл хийсэн юм гэж үү? Эсвэл махбодод байхдаа Тэрээр ямар ч эрх мэдэлгүй байснаас энэ нь болсон юм уу?

Миний ар хударгаар нууцхан үймүүлж, эсэргүүцэж байхад чинь Би мэддэггүй гэж чи бодоо юу? Ариун Сүнснээс авсан гэгээрлийн хэлтэрхийг Намайг эсэргүүцэхэд ашиглаж болно гэж чи бодоо юу? Петр төлөвшөөгүй байхдаа Есүсийн талаар олон санаа бодол өвөрлөсөн, тэгвэл яагаад тэр буруутгагдаагүй юм бэ? Яг одоо, олон хүн буруутгагдалгүйгээр аливааг хийж байгаа бөгөөд хийж байгаа зүйл нь буруу гэдгийг тодорхой хэлэх үед ч гэсэн тэд мөн л сонсдоггүй. Энэ нь бүхэлдээ хүний тэрслүү зангаас болоогүй гэж үү? Би сая маш их зүйл хэлсэн боловч чамд мөс чанарын мэдрэмж өчүүхэн ч байдаггүй, тэгвэл чи яаж замын сүүлчийн хэсгийг дуустал алхаж, замын төгсгөл хүртэл алхсаар байж чадах юм бэ? Энэ нь томоохон асуудал гэдгийг чи мэдэрч байна уу?

Хүмүүс байлдан дагуулагдсаныхаа дараа Бурханы зохион байгуулалтад захирагдаж чаддаг; тэдэнд итгэл болон Бурханыг хайрлах хүсэл зоригийн аль аль нь байдаг бөгөөд тэд Түүнийг дагахдаа эдгээрт тулгуурладаг. Иймээс замын сүүлчийн хэсэгт хэрхэн алхаж болох вэ? Гай зовлон туулах өдрүүддээ чи бүх бэрхшээлийг тэвчих ёстой ба зовох хүсэлтэй байх ёстой; ийм маягаар л чи замын энэ хэсгийг сайн туулж чадна. Замын энэ хэсгийг туулах маш амархан гэж чи бодож байна уу? Чи ямар чиг үүрэг гүйцэтгэхээ мэддэг байх ёстой; та нар хэв чанараа өсгөж, хангалттай үнэнээр зэвсэглэх ёстой. Энэ бол ганц хоёр хоногийн ажил биш бөгөөд чиний бодож байгаа шиг энгийн бус! Замын сүүлчийн хэсэгт алхах нь үнэндээ ямар итгэл, ямар хүсэлтэй байгаагаас чинь шалтгаална. Магадгүй чи Ариун Сүнс дотор чинь ажиллаж байгааг харж чадахгүй буюу чуулганаас Ариун Сүнсний ажлыг олж илрүүлж чаддаггүй болохоор гутранги, сэтгэл дундуур, урдах замдаа цөхрөлөөр дүүрэн байдаг байж болно. Ялангуяа, эртний агуу дайчид бүгд мөхсөн—энэ бүхэн чиний хувьд цохилт биш гэж үү? Эдгээр зүйлийг чи яаж харах ёстой вэ? Чамд итгэл байна уу, үгүй юү? Чи өнөөдрийн ажлыг бүрэн ойлгож байна уу, үгүй юү? Эдгээр зүйл замын сүүлчийн хэсэгт амжилттай алхаж чадах эсэхийг чинь тодорхойлж чадна.

Та нар одоо замын төгсгөлийн зурвас дээр байна гэж яагаад хэлдэг вэ? Учир нь та нар ойлгох ёстой бүх зүйлээ ойлгосон, Би та нарт хүмүүсийн хүрэх ёстой бүхнийг хэлсэн. Би бас та нарт даалгасан бүх зүйлийн тухай хэлсэн. Иймээс та нарын одоо алхаж яваа зүйл бол хүмүүсийг удирдан хөтөлдөг замын минь сүүлчийн хэсэг юм. Би та нараас бие даан амьдрах чадвартай болохыг л шаарддаг; чи үргэлж, цаг ямагт явах замтай байж, урьдынх шигээ хэв чанараа дээшлүүлж, Бурханы үгийг хэвийн уншиж, хэвийн хүний амьдралаар амьдарна. Одоо Би чамайг ийм маягаар амьдрахад хөтөлж байгаа боловч ирээдүйд Би чамайг удирдаагүй байх үед чи ингэж бас л чадах уу? Чи үргэлжлүүлэн явж чадах уу? Петрийн туршлага ийм байсан: Есүс түүнийг удирдаж байх үед түүнд ямар ч ойлголт байгаагүй; тэр үргэлж хүүхэд шиг санаа амар байж, хийж буй зүйлдээ нухацтай ханддаггүй байв. Есүсийг явж одсоны дараа л тэр хэвийн хүний амьдралаа эхлүүлсэн. Есүсийг явсны дараа л утга учиртай амьдрал нь эхэлсэн. Хэдийгээр тэр

хэвийн хүн чанарын зарим эрүүл ухааныг эзэмшиж, хэвийн хүний эзэмших ёстой зарим зүйлийг эзэмшдэг байсан боловч Есүсийг явах хүртэл жинхэнэ туршлага болон эрэл хайгуул нь шинээр эхлээгүй юм. Та нарын одоогийн нөхцөл байдал ямар байна вэ? Би одоо та нарыг ийм маягаар удирдаж, чи үүнийг гайхалтай гэж боддог. Чамд тохиолддог ямар ч орчин, шалгалт байхгүй ч ийм маягаар үнэндээ ямар биеийн хэмжээтэйг чинь харах аргагүй, мөн үнэхээр үнэнийг эрэлхийлдэг хүн мөн эсэхийг чинь ч харах аргагүй. Чи гол чанараа ойлгодог гэж өөрийн амаар хэлдэг ч эдгээр нь хоосон үг юм. Ирээдүйд бодит баримтууд чам дээр ирэх үед л ойлголт чинь батлагдана. Одоо чи иймэрхүү ойлголттой байгаа: “Махан бие минь маш их завхарсан, хүмүүсийн махан биеийн гол чанар нь Бурханы эсрэг тэрсэлж, эсэргүүцдэг гэдгийг би ойлгодог. Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авч чадна гэдэг нь хүмүүсийг өргөх Түүний арга зам юм. Би тэрийг одоо ойлгосон, бас Бурханы хайрыг хариулахыг хүсэж байна.” Гэвч үүнийг хэлэхэд амархан. Хожим нь гай зовлон, шалгалт, зовлон чам дээр ирэхэд энэ бүхнийг туулахад амаргүй байх болно. Та нар ийм маягаар өдөр бүр дагадаг боловч өөрсдийн туршлагыг үргэлжлүүлж мөн л чаддаггүй. Хэрэв Би та нарыг сул тавьж, огт анхаарахаа больсон бол бүр ч дор байх байсан; ихэнх хүн унаж, ичгүүрийн тэмдэг болох давсан багана болж хувирна. Ийм зүйлс тохиолдох тун боломжтой. Чи энэ талаар санаа зовох юм уу түгшихгүй байна уу? Петр тийм орчныг туулж, тийм зовлон амссан боловч бат зогсож чадсан юм. Хэрэв чи ийм орчин туулсан бол бат зогсож чадах байсан уу? Газар дээр байхдаа Есүсийн хэлсэн зүйл, хийсэн ажил Петрт суурь болж өгсөн бөгөөд энэхүү сууриас эхлэн тэр өөрийнхөө хожмын замаар алхсан билээ. Та нар тэр түвшинд хүрч чадах уу? Та нарын алхсан зам, ойлгосон үнэн—эдгээр нь ирээдүйд бат зогсох суурь чинь болж чадах уу? Эдгээр зүйл хожим бат зогсох үзэгдэл чинь болж чадах уу? Би та нарт үнэнийг хэлье—одоо хүмүүсийн ойлгодог зүйл бүгд хоосон сургаал юм гэж хэлж болно. Яагаад гэвэл, тэд ойлгодог бүх зүйлээ туулаагүй байдаг. Чи өдий хүртэл үргэлжлүүлж чадсан нь тэр чигтээ, шинэ гэрэл чамайг хөтөлснөөс болж байгаа. Чиний биеийн хэмжээ тодорхой түвшинд хүрсэн юм биш, харин Миний үг чамайг өнөө хүртэл удирдсанаас болж байгаа юм; чи агуу итгэлтэйдээ бус, харин чамайг өнөөг хүртэл дагахаас өөр аргагүй болгосон Миний үгийн мэргэн ухаанаас болж байгаа юм. Хэрэв Би одоо яриагүй бол, дуу хоолойгоороо айлдаагүй бол чи цааш явж чадахгүй болж, урагшлахаа нэн даруй болих байсан. Энэ нь та нарын бодит биеийн хэмжээ бус уу? Та нар аль тал руу орж, дутаж байгаа зүйлээ аль тал дээр нөхөх талаар огт мэддэггүй. Та нар утга учиртай амьдралаар хэрхэн амьдарч, Бурханы хайрыг хэрхэн хариулах, эсвэл хүчирхэг, цангинасан гэрчлэл яаж хийхийг ойлгодоггүй. Та нар энэ бүхэнд хүрэх ямар ч чадваргүй. Та нар залхуу дээрээ бас тэнэг. Та нар өөр зүйлд тулгуурлаж л болох ба тулгуурлах зүйл чинь шинэ гэрэл болон урд чинь чамайг хөтлөн явж буй Нэгэн билээ. Чи өнөөг хүртэл цөхрөлтгүй үргэлжлүүлж чадсан нь бүхэлдээ, шинэ гэрэл болон хамгийн сүүлийн үеийн айлдваруудад

тулгуурласнаас болж байгаа юм. Та нар үнэн замыг эрэлхийлэхдээ чадамгай байсан Петртэй огт адилгүй, эсвэл Еховад үнэнчээр шүтэн мөргөж, өөрийг нь яаж ч туршсан бай, ерөөсөн ч бай, үгүй ч бай Ехова бол Бурхан гэдэгт итгэсэн Иовтой адилгүй. Чи тийнхүү үйлдэж чадах уу? Та нар хэрхэн байлдан дагуулагдсан бэ? Нэг тал нь шүүлт, гэсгээлт, хараал, нөгөө тал нь та нарыг байлдан дагуулдаг нууцууд юм. Та нар бүгд илжиг шиг байдаг. Миний ярьдаг зүйл та нарын хувьд хангалттай сүрлэг биш бөгөөд ямар ч нууц байхгүй байвал та нарыг байлдан дагуулах боломжгүй байдаг. Хэрэв номлол айлддаг хүн байгаад, хэсэг хугацааны туршид нэг л зүйлийн талаар үргэлж номлосон бол та нар бүгд хоёр жилийн дотор тарж явах байсан; та нар үргэлжлүүлж чадахгүй байх байсан. Та нар хэрхэн гүнзгийрэхээ мэддэггүй, үнэнийг эсвэл амийн замыг хэрхэн эрэлхийлэхээ ч ойлгодоггүй. Та нарын ойлгодог бүхэн чинь нууц эсвэл үзэгдлийн талаар, Бурхан хэрхэн ажилладаг байсан, Петрийн туршлага, Есүсийн цовдлолын цаад шалтгааныг сонсох гэх мэт шинэ санагдах зүйлсийг хүлээн авах явдал юм… Та нар энэ талаар сонсоход л бэлэн байдаг, сонсох тусам улам их эрч хүчтэй болдог. Та нар уйтгар, гунигаа хөөх гэж л энэ бүхнийг сонсож байгаа. Та нарын амьдралыг бүхэлд нь эдгээр шинэ зүйл тэтгэдэг. Чи өнөөдрийн байгаа газартаа өөрийнхөө итгэлээр хүрсэн гэж бодож байна уу? Энэ чинь та нарын ялихгүй, өрөвдөлтэй өчүүхэн биеийн хэмжээ бус уу? Та нарын ёс жудаг хаана байна? Хүн чанар хаана байна? Та нарт хүний амьдрал байдаг уу? Төгс болгуулах элементээс хэд нь чамд байдаг вэ? Миний хэлж байгаа зүйл баримт биш гэж үү? Би ийм маягаар ярьж, ажилладаг боловч та нар бараг анхаарал хандуулдаггүй хэвээр байдаг. Та нар дагахдаа бас ажигладаг. Та нар үргэлж хайхрамжгүй царай гаргадаг бөгөөд үргэлж хамраасаа дөрлүүлдэг. Та бүхэн ингэж явж ирсэн; гагцхүү гэсгээлт, цэвэршүүлэлт, цээрлүүлэлт л өнөөдрийн байгаа газарт чинь хөтөлж авчирсан. Амийн оролтын тухай хэдэн номлол л номлоод байсан бол та нар бүгд аль эрт зугтаж алга болох байсан бус уу? Та нар нэг нь нөгөөгөөсөө илүү хямсгар боловч бодит байдал дээр гэдэс чинь гагцхүү бохир усаар дүүрсэн! Чи цөөн хэдэн нууц, урьд өмнө нь хүмүүсийн ойлгож байгаагүй зарим зүйлийг ойлгож авсан учраас л одоог хүртэл туйлбартай байж чадсан. Та нарт дагахгүй байх шалтгаан байгаагүй учраас өөрсдийгөө бараг л хатамжилж байж, олныг дагаж чадсан. Энэ бол ердөө л Миний үгээр хүрсэн үр дүн бөгөөд та нарын өөрсдөө биелүүлсэн үйл хэрэг яавч биш. Та нарт гайхуулах юм юу ч байхгүй. Тиймээс ажлын энэ үе шатанд та нар голчлон үгээр дамжуулан өдий хүрсэн. Эс бөгөөс та нарын дундаас хэн чинь дуулгавартай дагаж чадах байсан бэ? Хэн өнөөдрийг хүртэл туйлбартай байж чадах байсан бэ? Аль эртнээс та нар эхний боломж гарах мөчид явахыг хүсэж байсан боловч тэгж зүрхлээгүй; та нарт зориг дутагдсан. Өнөөдрийг хүртэл та нар шийдэмгий бусаар дагасаар ирсэн.

Есүс загалмайд цовдлогдож, явсны дараа л Петр өөрийн замналаар явж, явах ёстой замаараа алхаж эхэлсэн; тэр хангалтгүй байдал, дутагдлаа харсны дараа л зэвсэглэж эхэлсэн. Бурханыг гэх хайр нь дэндүү бага, зовох хүсэл нь хангалтгүй,

ямар ч мэдлэг ухаан байхгүй, эрүүл ухаанаар дутмаг байснаа тэр олж харсан. Есүсийн хүсэлтэй нийцэхгүй олон зүйл түүнд байгааг, тэрслүү, эсэргүү, хүний хүслээр сэвтсэн олон зүйл байгааг тэр олж харсан. Үүний дараа л тэр бүх талаар оролтыг олж авсан. Есүс түүнийг удирдаж байхдаа түүний байр байдлыг ил болгож, Петр үүнийг нь хүлээн зөвшөөрч, Есүсийн хэлсэнтэй санаа нийлсэн хэдий ч хожим нь болтол жинхэнэ ойлголт түүнд дутагдсаар байсан. Учир нь тухайн үед түүнд туршлага ч байгаагүй, өөрийн биеийн хэмжээний талаарх мэдлэг ч байгаагүй. Өөрөөр хэлбэл, Би одоо та нарыг удирдан хөтлөхдөө зөвхөн үг ашиглаж байгаа бөгөөд та нарыг богино хугацааны дотор төгс болгох боломжгүй, мөн та нар үнэнийг ойлгож, мэдэж чаддаг байхаар хязгаарлагдана. Учир нь чамайг байлдан дагуулж, зүрх сэтгэлд чинь үнэмшүүлэх нь одоогийн ажил бөгөөд хүмүүсийг байлдан дагуулсны дараа л зарим нь төгс болгуулна. Яг одоо, чиний ойлгодог тэдгээр үзэгдэл болон үнэн ирээдүйн туршлагын чинь суурийг тавьж байна; хожмын гай зовлонд та нар бүгд эдгээр үгийг бодитоор туулна. Хожим нь шалгалт ирж, гай зовлон туулах үедээ чи өнөөдөр хэлдэг “Ямар ч гай зовлон, шалгалт, их гамшигтай тулгарсан, би Бурханыг сэтгэл хангалуун байлгах ёстой” хэмээх үгийг бодох болно. Петрийн туршлагын талаар, дараа нь Иовын туршлагын талаар бодоод үз—чи өнөөдрийн үгээр урамшина. Зөвхөн ийм маягаар л итгэл чинь зоригжиж чадна. Тухайн үед Петр өөрийгөө Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээж авах эрхгүй гэж хэлсэн бөгөөд цаг нь ирэхэд чи ч бас өөрөөрөө дамжуулан Бурханы зөвт зан чанарыг бүх хүнд харуулахдаа бэлэн байх болно. Түүний шүүлт, гэсгээлтийг чи дуртайяа хүлээн авч, Түүний шүүлт, гэсгээлт, хараал чамд тав тух болно. Одоо, үнэнээр зэвсэглэхгүй байх чинь ердөө хүлээн зөвшөөрөхийн аргагүй юм. Үүнгүйгээр чи ирээдүйд бат зогсож чадахгүй төдийгүй, одоогийн ажлыг туулж чадахгүй байж магадгүй. Тэгвэл чи таягдан хаягдаж, шийтгэгдэх хүмүүсийн нэг болох бус уу? Яг одоо, чам дээр ирсэн ямар ч баримт байгаагүй, дутагдаж байгаа аль ч талаар чинь Би чамайг хангасан; Би бүх талаас ярьдаг. Та нар тийм ч их зовлон туулаагүй; ямар ч төлөөс төлөлгүйгээр бэлэн байгаа зүйлийг авдаг, түүнээс ч илүүтэйгээр, та нарт өөрийн гэсэн жинхэнэ туршлага, мэдлэг ухаан байдаггүй. Тиймээс та нарын ойлгодог зүйл бол жинхэнэ биеийн хэмжээ чинь биш. Та нар ойлгох, мэдэх, харахаар хязгаарлагддаг боловч нэг их үр дүнд хүрээгүй. Хэрэв Би та нарт хэзээ ч анхаарал хандуулаагүй, харин гэрт чинь туршлагажуулсан бол та нар асар уудам дэлхий ертөнц рүү аль эрт гүйж одох байсан. Ирээдүйд алхах зам чинь зовлонгийн замнал байна, хэрэв чи замын одоогийн энэ хэсэгт амжилттай алхвал ирээдүйд илүү их гай зовлон туулах үедээ гэрчлэлтэй байх болно. Хэрэв чи хүний амьдралын ач холбогдлыг ойлгодог, хүний амьдралын зөв замд орсон бөгөөд ирээдүйд Бурхан чамд яаж ч хандсан ямар ч гомдол, сонголтгүйгээр Түүний эрхээр захирагддаг, Бурханд ямар ч шаардлага тавьдаггүй бол чи ийм маягаар үнэ цэнтэй хүн болно. Яг одоо чи гай зовлон туулаагүй байгаа учраас аливаа зүйлийг ялгалгүйгээр дуулгавартай дагаж чадна. Бурхан яаж ч хөтөлсөн бай, тэр зам нь

сайн, Түүний бүх зохион байгуулалтад захирагдана гэж чи хэлдэг. Бурхан чамайг гэсгээсэн ч бай, хараасан ч бай, чи Түүнийг сэтгэл хангалуун байлгахад бэлэн байх болно. Гэсэн ч чиний одоо хэлдэг зүйл биеийн хэмжээг чинь төлөөлөх албагүй. Одоо хийхийг хүсдэг зүйл чинь чамайг эцсээ хүртэл дагах чадвартай гэдгийг харуулж чадахгүй. Асар их гай зовлон чам дээр ирэх үед, эсвэл хавчлага, дарамт, бүр илүү их шалгалт туулах үедээ чи эдгээр үгийг хэлж чадахгүй. Тэр үед чи ийм ойлголттой байж, бат зогсож чадвал энэ нь чиний биеийн хэмжээ байх болно. Тухайн үед Петр ямар байсан бэ? Петр: “Эзэн минь, би өөрийн амийг Таны төлөө золиосолно. Хэрэв Та намайг үхүүлбэл би үхнэ!” гэж хэлсэн. Тухайн үед тэр ингэж залбирдаг байсан. Тэрээр мөн: “Бусад хүн Таныг хайрлахгүй байсан ч гэсэн би эцсээ хүртэл Таныг хайрлах ёстой. Би Таныг цаг үргэлж дагана” гэж хэлсэн. Тухайн үедээ тэр ингэж хэлж байсан боловч өөр дээр нь шалгалт ирэнгүүт тэр нуран унаж, уйлсан. Петр Эзэнийг гурвантаа үгүйсгэснийг та нар бүгд мэдэж байгаа биз дээ? Шалгалт өөрсөд дээр нь ирэхэд уйлж, хүний сул дорой байдлыг харуулах олон хүн байдаг. Чи өөрийнхөө эзэн нь биш. Үүнд чи өөрийгөө хянаж чадахгүй. Магадгүй өнөөдөр чи үнэхээр сайн байгаа байж болох боловч тохиромжтой орчинд байгаа болохоор тэр юм. Маргааш тэр нь өөрчлөгдвөл чи хулчгар зан, чадваргүй байдал, жигшүүртэй, үнэ цэнгүй байдлаа харуулна. Чиний “эршүүд байдал” аль эрт юу ч биш болж, заримдаа чи бүр даалгавраа нэг тийш нь хаяад, яваад өгч ч магадгүй. Энэ нь тухайн үед ойлгосон зүйл чинь чиний жинхэнэ биеийн хэмжээ биш байсныг харуулдаг. Хүн Бурханыг үнэхээр хайрладаг эсэх, үнэхээр Бурханы эрхээр захирагдаж чаддаг эсэх, Бурханы шаарддаг зүйлийг биелүүлэхэд бүх хүчээ дайчилж чаддаг эсэх, Бурханд үнэнч хэвээр байж, амиа золиослох байсан ч гэсэн бүх зүйлийн хамгийн сайныг нь Бурханд өгдөг эсэхийг харахын тулд хүний жинхэнэ биеийн хэмжээг харах ёстой.

Эдгээр үгийг одоо хэлчихсэн гэдгийг чи санах ёстой: Хожим нь чи илүү их гай зовлон, илүү их зовлон зүдүүр туулна! Төгс болгуулах нь энгийн, амархан зүйл биш. Ядаж л Иовынх шиг, эсвэл түүнийхээс ч илүү их итгэл чамд байх ёстой. Ирээдүйн шалгалт Иовын шалгалтаас ч илүү их байх бөгөөд урт хугацааны гэсгээлт туулсаар байх ёстой гэдгээ чи мэдэх хэрэгтэй. Энэ энгийн зүйл гэж үү? Хэв чанараа сайжруулж чадахгүй бол, ойлгох чадвар чинь дутуу дулимаг байвал, мөн хэтэрхий багыг мэддэг бол тэр үед чамд ямар ч гэрчлэл байхгүй, харин Сатаны тоглоом, зугаа болох болно. Үзэгдлийг одоо хадгалж чадахгүй бол чамд ямар ч суурь байхгүй бөгөөд ирээдүйд чи хөсөр хаягдана! Замын аль ч хэсэг нь явахад амархан биш тул үүнийг хөнгөхнөөр бүү авч үз. Үүнийг одоо сайтар дэнсэлж үзээд бэлтгэлээ хий, ингэснээр энэ замын сүүлчийн хэсэгт зохих ёсоор алхаж болох юм. Энэ бол ирээдүйд алхах ёстой, бүх хүний алхах ёстой зам юм. Энэ ойлголтыг анхааралгүй өнгөрөөх ёсгүй; чамд Миний хэлдэг зүйл бүгд дэмий байдаг гэж бүү бод. Энэ бүхнийг сайтар ашиглах өдөр чамд ирнэ—Би үгээ хий дэмий айлдсан байж болохгүй. Энэ бол өөрийгөө зэвсэглэх, ирээдүйн замыг засах үе билээ. Чи хожим

алхах ёстой замыг бэлдэх хэрэгтэй; чи ирээдүйд хэрхэн бат зогсож чадах талаараа санаа зовж, сэтгэл түгшин, ирээдүйн замдаа сайн бэлдэх ёстой. Ховдог, залхуу бүү бай! Цаг хугацаагаа хамгийн сайн ашиглахын тулд чадах бүх зүйлээ бүгдийг нь хийх ёстой, ингэснээр чи хэрэгтэй бүхнээ олж авч магад. Чамайг ойлгоосой гэсэндээ Би бүхнийг чамд өгч байна. Гурав хүрэхгүй жилийн дотор Би маш олон зүйл хэлж, маш их ажил хийснийг чи өөрийн нүдээр харсан. Ийм маягаар ажиллаж ирсний минь нэг шалтгаан нь хүмүүс маш их дутуу дулимаг бөгөөд нөгөө нэг шалтгаан нь цаг хугацаа хэтэрхий богино; цаашид хойшлуулж болохгүй. Хүмүүс гэрчлэл хийж, ашиглагдахаасаа өмнө эхлээд дотроо тов тодорхой байдалд хүрэх ёстой гэж чи төсөөлдөг, гэвч тэгэх нь хэтэрхий удаан байх бус уу? Тэгвэл Би чамайг хэр удаан дагалдах ёстой байх вэ? Өтөлж, бууралтталаа Би чамайг дагалдана гэвэл тэгэх боломжгүй! Илүү их гай зовлон туулснаар бүх хүн дотроо жинхэнэ ойлголтод хүрнэ. Эдгээр нь ажлын алхмууд юм. Чи өнөөдөр нөхөрлөсөн үзэгдлийг бүрэн ойлгож, жинхэнэ биеийн хэмжээтэй болмогцоо ирээдүйд ямар ч бэрхшээл туулсан цочирдохгүй, тэсвэрлэж чадна. Намайг ажлын энэхүү сүүлчийн алхмыг гүйцээж, эцсийн үгийг айлдаж дуусах үед ирээдүйд хүмүүс өөр өөрийн замаар алхах хэрэгтэй болно. Өмнө нь айлдсан үгийг энэ нь биелүүлнэ: Хүн нэг бүрд зориулсан даалгавар, хүн болгонд хийх ажил Ариун Сүнсэнд байдаг. Ирээдүйд хүн бүр Ариун Сүнсээр удирдуулан алхах ёстой замаараа алхана. Гай зовлон туулж байхдаа хэн бусдын төлөө санаа тавьж чадах вэ? Хувь хүн бүр өөрийн гэсэн зовлонтой байдаг, дор бүрнээ өөрийн гэсэн биеийн хэмжээтэй байдаг. Хэний ч биеийн хэмжээ өөр нэгнийхтэй ижилхэн байдаггүй. Нөхрүүд нь эхнэрүүдээ, эцэг эхчүүд нь хүүхдүүдээ халамжилж чадахгүй; хэн ч өөр хэн нэгний төлөө санаа тавьж чадахгүй. Энэ нь, харилцан халамжилж, дэмжих боломжтой хэвээр байгаа одоогийнх шиг байхгүй. Төрөл бүрийн хүнийг ил болгох үе байх болно. Өөрөөр хэлбэл, Бурхан хоньчныг цохиход хонин сүрэг тарж бутрах бөгөөд тэр үед та нарт ямар ч жинхэнэ удирдагч байхгүй байх болно. Хүмүүс хуваагдана—та нар хамт цугларч чаддаг одоогийнх шиг байхгүй. Ирээдүйд Ариун Сүнсний ажилгүй хүмүүс жинхэнэ төрхөө харуулна. Нөхрүүд эхнэрээсээ урваж, эхнэрүүд нөхрөөсөө урваж, хүүхдүүд нь эцэг эхээсээ урваж, эцэг эх нь хүүхдүүдээ хяхан хавчина—хүний зүрх сэтгэлийг ухан ойлгохын аргагүй! Хүний хувьд хийж болох бүхэн нь өөрт байгаа зүйлээ хадгалж, замын сүүлчийн хэсэгт зүй зохистой алхах явдал юм. Яг одоо та нар үүнийг тодорхой харахгүй байна; та нар бүгд харалган. Ажлын энэ алхмыг амжилттай туулах амар зүйл биш.

Гай зовлонгийн цаг үе хэтэрхий сунжрахгүй; үнэндээ нэг жилээс ч богино хугацаанд үргэлжилнэ. Хэрэв энэ нь нэг жил үргэлжлэх байсан бол ажлын дараагийн алхам хойшилж, хүмүүсийн биеийн хэмжээ хангалтгүй байх байсан. Хэтэрхий удаан байсан бол хүмүүс үүнийг тэсвэрлэж чадахгүй байх байсан. Эцсийн эцэст хүмүүсийн биеийн хэмжээ хязгаартай. Миний өөрийн ажил дууссаны дараа, хүмүүс алхах ёстой замаараа алхах нь дараагийн алхам юм. Хүн бүр ямар

замаар алхах ёстойгоо ойлгох ёстой—энэ нь зовох зам ба үйл явц, мөн Бурханыг хайрлах хүслийг чинь цэвэршүүлэх зам билээ. Чи ямар үнэнд орох ёстой, ямар үнэнийг нэмэх ёстой, хэрхэн туулах ёстой, аль талаас нь орох ёстой гээд энэ бүх зүйлийг ойлгох ёстой. Чи одоо өөрийгөө зэвсэглэх ёстой. Гай зовлон чам дээр ирэх үед хэтэрхий хожимдсон байх болно. Хүн бүр өөрийн амийн төлөө ачаа үүрэх ёстой бөгөөд бусдын сэрэмжлүүлэхийг болон бусад хүн чихнээс чинь чангаахыг үргэлж битгий хүлээ. Би маш ихийг хэлсэн байтал чи ямар үнэнд орох ёстой, ямар үнэнээр зэвсэглэх ёстойгоо одоо болтол мэддэггүй. Бурханы үгийг уншихад ямар ч хүчин чармайлт гаргаагүйг чинь энэ нь харуулдаг. Чи өөрийн амийн төлөө ямар ч ачаа үүрдэггүй—үүнийг яахан хүлээн зөвшөөрч болох билээ? Чи юунд орох ёстой талаар тодорхой мэддэггүй, юу ойлгох ёстойгоо ойлгодоггүй, ямар зам сонгож авах ёстой талаар учраа олохгүй хэвээр байгаа. Чи огт үнэ цэнгүй биш гэж үү? Чи ямар хэрэгтэй юм бэ? Та нарын одоо хийж байгаа зүйл өөрсдийн замыг тавьж, барьж байгуулах явдал. Чи хүмүүс юунд хүрэх ёстойг мэддэг, хүн төрөлхтөнд тавьдаг Бурханы шаардлагын стандартыг мэддэг байх ёстой. Дараах ойлголт чамд байх ёстой: Юу ч болсон гэсэн, би гүн гүнзгий завхарсан байсан ч Бурханы өмнө тэрхүү дутагдлаа нөхөх ёстой. Бурхан надад хэлэхээс өмнө би ойлгодоггүй байсан боловч одоо Тэр надад хэлж, би ойлгосон болохоор би яаран дутагдлаа засаж, хэвийн хүн чанарыг амьдран харуулж, Бурханы хүсэлд нийцэж чадах дүр төрхийг амьдран харуулах ёстой. Би Петрийн хийсэнд хүрч чадахгүй байсан ч гэсэн ядаж л хэвийн хүн чанарыг амьдран харуулах ёстой. Ийм маягаар би Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгаж чадна.

Энэ замын сүүлчийн хэсэг одоогоос эхлээд ирээдүйн гай зовлон дуусах хүртэл үргэлжилнэ. Замын энэ хэсэг нь хүмүүсийн жинхэнэ биеийн хэмжээ илчлэгдэхийн зэрэгцээ тэдэнд жинхэнэ итгэл байдаг эсэхийг харуулах үе юм. Замын энэ хэсэг хүмүүсийн урьд өмнө хөтлүүлж явж байсан аль ч замаас илүү хүнд бэрх, бартаатай байх учраас “замын сүүлчийн хэсэг” гэж нэрлэдэг. Үнэндээ энэ нь замын хамгийн сүүлийн хэсэг биш; учир нь гай зовлон туулсны дараа чи сайн мэдээ түгээх ажлыг туулах бөгөөд ашиглагдах ажлыг туулах хэсэг хүн байх болно. Тиймээс хүмүүсийг цэвэршүүлэх гай зовлон болон хатуу ширүүн орчинтой холбоотойгоор л “замын сүүлчийн хэсгийн” талаар ярьдаг. Урьд нь алхсан замын тэр хэсэгт Би чамайг тэрхүү баяр хөөртэй аялалд биечлэн хөтөлж, гараас чинь хөтлөн чамд зааж, амнаасаа чамайг хооллосон. Хэдийгээр чи гэсгээлт, шүүлтийг олон удаа туулсан ч чиний хувьд тэдгээр нь ээлж дараалсан хөнгөхөн цохилтоос хэтрээгүй. Мэдээж энэ нь Бурханд итгэх итгэлийн талаарх үзэл бодлыг чинь нэлээд өөрчилсөн; мөн энэ нь зан чанарыг чинь нэлээд тогтворжуулж, Миний талаар багахан хэмжээний ойлголт олж авах боломжийг чамд олгосон. Гэвч Миний хэлж байгаа зүйл бол замын тэрхүү хэсгээр алхаж байх үедээ хүмүүсийн төлсөн төлөөс, уйгагүй хичээл зүтгэл зэгсэн бага байсан—Би л чамайг өдий хүртэл чинь хөтөлсөн. Учир нь Би чамаас ямар нэг юм хий гэж шаарддаггүй; үнэндээ Миний чамд тавьдаг шаардлага

минь огтхон ч өндөр биш—Би зүгээр л байгаа зүйлийг хүлээж авахыг чамд зөвшөөрдөг. Энэ хугацаанд Би та нарын хэрэгцээг тасралтгүй хангаж байсан бөгөөд хэзээ ч үндэслэлгүй шаардлага тавьж байгаагүй. Та нар олон удаагийн гэсгээлт амссан мөртөө Миний анхны шаардлагыг биелүүлээгүй. Та нар буцаж няцаж, гутардаг боловч Би үүнийг анхаарч үздэггүй, учир нь одоо бол Миний хувийн ажлын цаг үе бөгөөд Надад өгөх “зориулалтыг” чинь Би нухацтай авч үздэггүй. Гэвч үүнээс цааших зам дээр Би ажиллаж, үг хэлэхээ больж, цаг нь ирэхээр ийм хий дэмий байдлаар үргэлжлүүлэхийг чинь болиулна. Би та нарыг суралцах арвин их хичээлтэй байлгана, бэлэн байгаа зүйлийг та нараар авхуулахгүй. Өнөөдөр та нарт байгаа жинхэнэ биеийн хэмжээг ил болгох ёстой. Хэдэн жилийн хүчин чармайлт чинь эцэстээ үр дүнтэй байсан эсэх нь замын энэ сүүлчийн хэсэгт та нар хэрхэн алхахаас харагдана. Бурханд итгэх нь маш энгийн гэж урьд нь та нар боддог байсан бөгөөд Бурхан чамд хатуу чанга хандаж байгаагүй учраас тэр юм. Одоо тэгвэл ямар байна вэ? Бурханд итгэх нь энгийн гэж та нар боддог уу? Бурханд итгэх нь та нарыг гадаа тоглож буй хүүхдүүд шиг баяр хөөртэй, санаа зовох зүйлгүй болгодог гэж та нарт санагдсаар байна уу? Та нар хонь гэдэг нь үнэн; гэхдээ Бурханы нигүүлслийг хариулж, итгэдэг Бурханаа бүрэн олж авахын тулд алхах учиртай замаараа алхаж чаддаг байх ёстой. Өөрсдийгөө бүү доог тохуу болго, өөрсдийгөө бүү хуур! Замын энэ хэсэгт цөхрөлтгүй үргэлжлүүлж чадвал чи Миний сайн мэдээний ажил бүхий л орчлон ертөнц даяар түгэх урьд өмнө үзэгдээгүй үзэгдлийг харж чадах ба Миний дотнын хүн байж, Миний ажлыг орчлон ертөнц даяар өргөжихөд үүргээ гүйцэтгэх сайхан аз завшаан чамд тохионо. Тэр үед чи алхах ёстой замаараа баяртайгаар үргэлжлүүлэн алхана. Ирээдүй зах хязгааргүй гэгээлэг байна, харин одоо гол зүйл нь замын энэ сүүлчийн хэсэгт зүй зохистой алхах явдал юм. Чи эрж хайж, үүнийг хийхдээ бэлдэх ёстой. Энэ бол чиний яг одоо хийх ёстой зүйл; одоо энэ нь яаралтай асуудал юм!

ЧУУЛГАНУУДААР ЯВАХДАА ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ

III

(1993 ОНЫ 7-Р САР—1994 ОНЫ 3-Р САР)

ЧИ ИРЭЭДҮЙН ҮҮРЭГТЭЭ ХЭРХЭН ХАНДАХ ЁСТОЙ ВЭ?

Чи эрин үеийн ач холбогдлыг зохистой дамжуулдаг хэлээр, эрин үе бүрд Бурханы илэрхийлсэн зан чанарыг бодитой байдлаар ярьж чадах уу? Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг туулдаг чи Бурханы зөвт зан чанарыг нарийвчлан дүрсэлж чадах уу? Чи Бурханы зан чанарыг тодорхой, нарийн зөв гэрчилж чадах уу? Зөв шударга байдлаар өлсөж, цангадаг, өрөвдөлтэй, ядуу, чин сүсэгт, мөн чамаар хариулуулахаар хүлээж байгаа шашны итгэгчдэд чи өөрийн үзсэн, туулсан зүйлийг хэрхэн дамжуулах вэ? Чамаар хариулуулах гээд ямар янзын хүмүүс чамайг хүлээж байгаа бол? Чи төсөөлж чадах уу? Мөрөн дээрх ачаа, даалгавар, үүрэг хариуцлагаа чи мэдэж байна уу? Түүхэн үүрэг хариуцлагын мэдрэмж чинь хаана байна вэ? Чи яаж дараагийн эрин үеийн эзэн болох вэ? Чамд эзэн хүний хүчтэй мэдрэмж бий юу? Бүх зүйлийн эзэн гэдгийг чи хэрхэн тайлбарлах вэ? Энэ нь үнэхээр бүх амьд амьтан болон дэлхий дээрх бүх зүйлийн эзэн үү? Ажлын дараагийн үе шат руу урагшлах ямар төлөвлөгөө чамд байна вэ? Чамаар хариулуулахаар хэдэн хүн хүлээж байгаа вэ? Чиний даалгавар хүнд үү? Тэд ядуу, өрөвдөлтэй, сохор, аргаа барсан бөгөөд харанхуйд гасалж байна—зам хаана байна вэ? Харвах од мэт гэрэл гэнэт бууж, хүнийг маш олон жилийн турш дарангуйлсан харанхуйн хүчийг сарниулахыг тэд ямар их хүсэн эрмэлздэг билээ. Тэд ямар их дэнслэн найдаж, үүнийг өдөр шөнөгүй мөрөөдөж байгааг хэн мэдэх юм бэ? Гүнээ зовж буй энэ хүмүүс харанхуй гянданд хоригдсоор, гэрэл гялалзан өнгөрөх өдөр ч гэсэн суллагдах найдваргүй байдаг; тэд хэзээ гашуудан уйлахаа болих вэ? Амар заяа үзээгүй энэ сул дорой сүнснүүдийн золгүй явдал аймшигтай бөгөөд өршөөлгүй хүлээс болон цэвдэг түүх тэднийг аль хэдийн ийм байдалтай болгон хүлсэн. Тэдний гашуудан уйлах чимээг хэн сонссон бэ? Өрөвдмөөр байдлыг нь хэн харсан бэ? Бурханы зүрх сэтгэл хэчнээн гашуудаж, түгшиж байдгийг чи ер нь бодож үзэж байсан уу? Өөрийн гараар бүтээсэн гэмгүй хүн төрөлхтөн нь ийм тарчлаан амсаж байгааг Тэр яаж тэвчиж чадах юм бэ? Эцсийн эцэст, хүн төрөлхтөн бол хордсон хохирогчид. Хэдийгээр хүн өнөөг хүртэл золоор амьд үлдсэн ч гэсэн хүн төрөлхтнийг муу ёрын нэгэн аль хэдийн хордуулсан гэдгийг хэн мэдэх билээ? Чи хохирогчдын нэг гэдгээ мартчихсан уу? Бурханыг гэх хайраасаа болоод чи амьд үлдсэн энэ хүмүүсийг аврахаар чармайхыг хүсэхгүй байна уу? Хүн төрөлхтнийг Өөрийн мах цус шигээ хайрладаг Бурханы ачийг хариулахын тулд хамаг эрч хүчээ зориулахыг хүсэхгүй байна уу? Эцсийн эцэст Бурханаар ашиглуулан энэхүү ер бусын амьдралаар амьдрахыг чи хэрхэн ойлгодог вэ? Чамд үнэн сүсэгтэй, Бурханд үйлчилдэг хүний утга учиртай амьдралаар амьдрах шийдвэр болон итгэл үнэхээр байна уу?

ХҮН ТӨРӨЛХТНИЙГ УДИРДАХЫН ЗОРИЛГО

Хэрвээ хүмүүс хүний амьдралын зөв зам, мөн түүнчлэн хүн төрөлхтнийг удирдах Бурханы зорилгыг үнэхээр тодорхой харж чаддаг бол өөрсдийн ирээдүй, хувь заяаг зүрх сэтгэлдээ эрдэнэс мэт нандигнахгүй. Тэд гахай, нохойноос долоон дор эцэг эхдээ үйлчлэх сонирхолгүй болох байсан. Хүний ирээдүй, хувь заяа нь яг нарийндаа өнөө үеийн, Петрийн “эцэг эх” гээч зүйл биш гэж үү? Тэдгээр нь яг л хүний мах цус мэт байдаг. Махан биеийн хүрэх газар болон ирээдүй яг ямар байх вэ? Амьд ахуйдаа Бурханыг харах уу, эсвэл нас барсныхаа дараа сүнсээрээ Бурхантай уулзах уу? Махан бие маргааш гамшиг зовлонгийн асар том зууханд эцэслэх үү, эсвэл гал түймэр дотор байх уу? Хүний махан бие золгүй явдал амсах, эсвэл зовох эсэхтэй хамаатай иймэрхүү асуултууд нь одоогийн энэ урсгал дахь уураг тархитай, эрүүл ухаантай хэн болгоны хамгийн их санаа зовдог томоохон мэдээ биш гэж үү? (Энд, зовох гэдэг нь ерөөл хүлээн авахыг хэлдэг; хожмын шалгалтууд хүний хүрэх газарт ач тустай гэсэн үг юм. Золгүй явдал гэдэг нь бат зогсож чадахгүй байх, эсвэл мэхлэгдэхийг хэлдэг; эсвэл энэ нь, хүн золгүй нөхцөл байдалтай тулгарч, гай гамшгийн дунд амиа алдана, мөн хүний сүнсэнд тохиромжтой хүрэх газар байхгүй гэсэн утгатай.) Хүмүүс эрүүл саруул ухаантай байдаг хэдий ч боддог зүйл нь тэдний эрүүл ухаанд байх ёстой зүйлтэй бүрэн нийцдэггүй байж магадгүй. Учир нь тэд нэлээд будилдаг ба аливааг сохроор дагадаг. Тэд юунд орох учиртайгаа нэгд нэггүй ухаарч, ялангуяа гай зовлонгийн үеэр (өөрөөр хэлбэл, зууханд цэвэршүүлэгдэх үеэр) юунд орох ёстой, мөн галын шалгалтын үеэр юугаар зэвсэглэх ёстойгоо ялгаж салгах ёстой. Шавж хорхойноос ч долоон дор, гахай нохой шиг эцэг эхдээ (махан бие гэсэн үг) үргэлж битгий үйлчил. Хэт сэтгэлээ зовоож, их юм бодож, тархиа гашилгах ямар хэрэгтэй юм бэ? Махан бие чамд харьяалагддаггүй, харин ганцхан чамайг ч биш, бас Сатаныг захирдаг Бурханы гарт бий. (Махан бие анхнаасаа Сатанд харьяалагддаг гэсэн үг. Сатан ч гэсэн Бурханы гарт байдаг учраас үүнийг ингэж л хэлж болно. Учир нь ийм маягаар хэлэх нь илүү үнэмшилтэй; хүмүүс тэр чигтээ Сатаны эзэмшил дор байдаггүй, харин Бурханы гарт байдаг гэдгийг энэ нь хэлж өгдөг.) Чи махан биеийн тарчлаан дор амьдарч байгаа, гэхдээ махан бие чамд харьяалагддаг уу? Чиний хяналтан дор байдаг уу? Үүнээс болж тархиа гашилгах ямар хэрэгтэй юм бэ? Аль эртнээс яллагдаж, хараагдаж, бузар сүнсээр бузарлагдсан өмхий махан биеийнхээ төлөө чи Бурханаас улайран гуйх ямар хэрэгтэй юм бэ? Сатаны хамсаатанг зүрх сэтгэлдээ үргэлж ойрхон байлгах ямар хэрэгтэй юм бэ? Махан бие чиний жинхэнэ ирээдүй, гайхалтай итгэл найдвар, чиний амьдралын жинхэнэ хүрэх газрыг сүйрүүлж магадгүй гэдэгт чи санаа зовохгүй байна гэж үү?

Өнөөдрийн замаар алхахад амар биш. Олж авахад нэлээд бэрх бөгөөд эрин үеүдийн туршид энэ нь туйлын ховор байсан гэж хэлж болох юм. Гэсэн хэдий ч, хүнийг сүйрүүлэхэд махан бие нь дангаараа хангалттай гэж хэн бодох билээ?

Өнөөдрийн ажил хаврын бороо мэт нандин, хүнийг гэх Бурханы сайхан сэтгэл мэт үнэ цэнтэй нь гарцаагүй. Гэвч хүн Түүний одоогийн ажлын зорилгыг мэддэггүй, эсвэл хүн төрөлхтний мөн чанарыг ойлгодоггүй бол эрхэм нандин, үнэ цэнтэй байдлынх нь талаар ярьж яахан чадах билээ? Махан бие хүмүүст өөрсдөд нь харьяалагддаггүй тул үүний хүрэх газар үнэндээ хаана байхыг хэн ч тодорхой харж чаддаггүй. Ямартай ч бүтээлийн Эзэн бүтээгдсэн хүн төрөлхтнийг анхдагч байр суурь луу нь буцааж, бүтээлийн цаг үеийн анхдагч дүр төрхийг нь сэргээнэ гэдгийг чи сайтар мэдэж байх ёстой. Тэрбээр хүнд өгсөн амьсгалаа бүрмөсөн буцаан авч, түүний яс, махыг аваад, бүгдийг нь бүтээлийн Эзэнд эргүүлэн өгнө. Тэгээд хүн төрөлхтнийг бүрмөсөн өөрчлөн шинэчилж, анхнаасаа хүн төрөлхтөнд бус, Бурханд харьяалагдаж байсан Бурханы бүхий л өв хөрөнгийг хүнээс буцаан авах бөгөөд үүнийг хүн төрөлхтөнд дахин хэзээ ч өгөхгүй. Яагаад гэвэл, тэдгээр зүйлийн нэг нь ч анхнаасаа хүн төрөлхтөнд харьяалагдаж байгаагүй. Тэрээр бүгдийг нь буцаан авна—энэ нь шударга бус дээрэм биш, харин ч тэнгэр, газрыг анхдагч байдалд нь сэргээж, хүнийг өөрчлөн шинэчлэх учиртай юм. Энэ нь хүний хувьд боломжийн хүрэх газар хэдий ч хүмүүсийн төсөөлдөг шиг, гэсгээгдсэнийх нь дараа махан биеийг буцаан авах явдал биш байж магадгүй. Бурхан махан бие сүйрсний дараах араг ясыг хүсдэггүй; харин анхнаасаа Бурханд харьяалагдаж байсан хүний анхдагч элементүүдийг хүсдэг. Тиймээс Тэр хүн төрөлхтнийг устгахгүй, эсвэл хүний махан биеийг бүрмөсөн үгүй хийхгүй, учир нь хүний махан бие бол хүний хувийн өмч биш. Харин ч энэ нь хүн төрөлхтнийг захирдаг Бурханы хавсралт юм. Өөрийгөө “зугаацуулахын” тулд Тэр яаж хүний махан биеийг устгаж чадах юм бэ? Одоо чи сохор зоосны ч үнэ хүрэхгүй махан биеэ бүхэлд нь үнэхээр орхисон уу? Хэрвээ чи эцсийн өдрүүдийн ажлын гучин хувийг (энэхүү гучхан хувь бол Ариун Сүнсний өнөөдрийн ажил болоод эцсийн өдрүүд дэх Бурханы үгийн ажлыг ойлгох гэсэн үг) ойлгож чадсан бол өнөөдрийнх шиг олон жилийн турш завхарсан махан биедээ үргэлжлүүлэн “үйлчлэх” юм уу “ачлалтай” хандахгүй байх байсан юм. Хүмүүс одоо урьд өмнө үзэгдээгүйгээр ахиж дэвшсэн бөгөөд цаашид түүхийн хүрд мэт өнхөрсөөр байхаа болино гэдгийг чи тодорхой харах учиртай. Илжирсэн махан бие чинь аль эртнээс ялаагаар бүрхэгдсэн тул өнөөг хүртэл Бурханы үргэлжлүүлсэн түүхийн хүрдийг буцаан эргүүлэх хүч үүнд яахан байх билээ? Чимээгүйхэн цохилох эцсийн өдрүүдийн цагийг дахин чаг чаг цохилуулж, зүүг нь нар зөв эргүүлсээр байж яахан чадах билээ? Өтгөн манангаар хучигдсан мэт санагдах дэлхий ертөнцийг дахин хувиргаж яахан чадах билээ? Чиний махан бие уулс болон гол мөрнийг сэргээж чадах уу? Багахан чиг үүрэгтэй махан бие чинь чиний хүсэн эрмэлзэж байсан хүмүүний ертөнцийг үнэхээр сэргээж чадна гэж үү? Чи үр удмаа “хүн” болгон хүмүүжүүлж үнэхээр чадах уу? Чи одоо үүнийг ойлгож байна уу? Чиний махан бие яг юунд харьяалагддаг вэ? Хүнийг аврах, төгс болгох, өөрчлөх гэсэн Бурханы анхдагч санаа зорилго нь чамд гайхалтай сайхан эх нутаг өгөх юм уу хүний махан биед амар тайван амралтыг авчрахын төлөө байгаагүй; энэ нь Түүний

алдар суу, Түүний гэрчлэлийн төлөө, хүн төрөлхтний хожмын илүү сайхан зугаа цэнгэлийн төлөө байсан, ингэснээр тэд төд удалгүй амарч чадах юм. Гэсэн ч энэ нь махан биеийн чинь төлөө байдаггүй, учир нь хүн бол Бурханы удирдлагын үндсэн хөрөнгө бөгөөд хүний махан бие бол ердөө л хавсралт билээ. (Хүн бол сүнс болон биетэй объект, харин махан бие бол ердөө л илжирч мууддаг зүйл. Махан бие бол удирдлагын төлөвлөгөөнд ашиглагддаг багаж хэрэгсэл гэсэн үг юм.) Бурхан хүмүүсийг төгс болгож, бүрэн дүүрэн болгож, олж авах нь тэдний махан биед илд болон цохилт, мөн түүнчлэн эцэс төгсгөлгүй зовлон, галын шатаалт, өршөөлгүй шүүлт, гэсгээлт, хараал, дуусашгүй олон шалгалтыг л авчирдаг гэдгийг чи мэдэх учиртай. Энэ нь хүнийг удирдах ажлын дотоод түүх болон үнэн юм. Гэсэн ч энэ бүх зүйл хүний махан биед чиглэдэг бөгөөд дайсагналын сум хүний махан бие рүү хайр найргүйгээр онилдог (учир нь хүн гэмгүй). Энэ бүхэн Түүний алдар суу болон гэрчлэлийн төлөө, мөн Түүний удирдлагын төлөө байдаг. Учир нь Түүний ажил ганцхан хүн төрөлхтний төлөө байдаггүй, харин бүхий л төлөвлөгөөний төлөө, түүнчлэн хүн төрөлхтнийг бүтээх үеийн Түүний анхдагч хүслийг биелүүлэхийн төлөө байдаг. Тиймээс хүний туулдаг зүйлийн ерэн хувь нь зовлон болон галын шалгалтуудыг агуулж магадгүй бөгөөд хүний махан биеийн хүсэн хүлээсэн аз жаргалтай, сайхан өдрүүд маш цөөхөн байдаг, эсвэл бүр огт байдаггүй. Хүн махан биеэр аз жаргалтай хором мөчийг эдэлж, Бурхантай хамт сайхан цаг хугацааг өнгөрүүлж бүр ч чаддаггүй. Махан бие бузар тул хүний махан бие Бурханы гэсгээлтийг л хардаг, эсвэл эдэлдэг ба энэ нь хэвийн эрүүл ухаангүй мэт, хүн үүнийг хайхрамжгүй гэж үздэг. Учир нь Бурхан “хүнийг хайхардаггүй”, хүний халдахыг тэвчдэггүй, мөн дайснуудаа үзэн яддаг зөвт зан чанараа харуулна. Бурхан боломжит бүх аргаар дамжуулан Өөрийн бүх зан чанарыг ил тод илчилж, улмаар Сатантай хийсэн зургаан мянган жилийн тулааны ажил буюу бүх хүн төрөлхтнийг аварч, хуучны Сатаныг устгах ажлаа төгсгөнө!

ХҮНИЙ МӨН ЧАНАР БА ЯЛГАМЖ ЧАНАР

Үнэндээ израильчууд сэтгэл дундуур байгаагүй; өнгөрсөн зургаан мянган жилийн хугацаанд Бурханы хийсэн ажлыг харсан, учир нь Би тэднийг орхиогүй билээ. Харин ч, муу ёрын нэгний бэлэглэсэн сайн мууг мэдүүлэгч модны жимсийг өвөг дээдэс нь идсэн учраас тэд нүглийн төлөө Намайг орхисон юм. Сайн нь үргэлж Надад харьяалагдсаар ирсэн байхад ёрын муу нь нүглийн төлөө Намайг аргалдаг муу ёрын нэгэнд харьяалагддаг. Би хүмүүсийг буруутгадаггүй, мөн тэднийг хайр найргүй хядаж, өршөөлгүй гэсгээлтэд өртүүлдэг ч үгүй, учир нь ёрын муу анхнаасаа хүн төрөлхтөнд харьяалагдаж байгаагүй. Тиймээс, тэр израильчууд Намайг олны өмнө загалмайд цовдолсон хэдий ч Мессиа болон Еховаг хүлээж, Аврагч Есүсийг хүсэн тэмүүлсээр ирсэн тэд Миний амлалтыг хэзээ ч мартаагүй: Учир нь Би тэднийг

хаяагүй юм. Эцсийн эцэст Би хүн төрөлхтөнтэй байгуулсан гэрээнийхээ баталгаа болгон цусыг сонгож авсан; энэхүү баримт нь гэм зэмгүй, залуу хүмүүсийн зүрх сэтгэлд бичигдсэн “цусан гэрээ” болсон бөгөөд тамга шиг, мөн тэнгэр газар мэт мөнхөд харилцан хамааралтай байдаг. Өөрийн урьдчилан тогтоож, сонгож, дараа нь золин аварч, олж авсан, Намайг муу ёрын нэгнээс илүү хайрладаг тэр гунигт сүнснүүдийг Би хэзээ ч хуураагүй учраас тэд Миний эргэн ирэхийг тэсэн ядан хүлээж, Надтай уулзахаар тэмүүлэн хүлээж байдаг. Тэдэнтэй цусаар байгуулсан гэрээгээ Би хэзээ ч арилгаагүй болохоор тэд чин сэтгэлээсээ хүлээсээр ирсэн нь гайхах зүйл биш. Би олон жилийн турш төөрсөн эдгээр хургыг эргүүлэн олж авна, учир нь Би хүмүүсийг үргэлж хайрлаж байсан билээ; гагцхүү тэдний сайн сайхан дээр муу ёрын элементүүд нэмэгдчихсэн юм. Намайг хайрладаг агаад Өөрийн удаан хугацаанд хайрласан өрөвдөлтэй сүнснүүдийг Би олж авах боловч Намайг хэзээ ч хайрлаагүй бөгөөд дайснууд мэт авирласан тэр ёрын муу хүмүүсийг яаж гэртээ аваачиж чадах билээ? Би хүмүүстэй цусаар гэрээ байгуулсан хэдий ч Намайг үзэн ядаж, эсэргүүцэж, сөрж, дайран давшилж, хараадаг диавол болон хорт могойн үр удмыг Өөрийн хаанчлал руу аваачихгүй. Миний ажлын зорилго юу болохыг, мөн Би үүнийг хэний төлөө хийдгийг чи яг таг мэдэх учиртай. Чиний хайр сайныг агуулдаг уу, эсвэл мууг уу? Миний талаарх мэдлэг чинь Давид, Мосе нарынхтай ижилхэн үү, үгүй юу? Надад үйлчилж байгаа чинь Абрахамынхтай адилхан уу, үгүй юу? Чи үнэхээр Надаар төгс болгуулж байгаа боловч хэнийг төлөөлөхөө, мөн хэнтэй адил үр дүнтэй байхаа мэдэх ёстой. Миний ажлыг туулснаар чи насан туршдаа баяр хөөртэй, элбэг дэлбэг ургац хураасан уу? Энэ нь элбэг арвин, үржил шимтэй юу? Чи өөрийгөө эргэцүүлэх ёстой: Олон жилийн турш Миний төлөө уйгагүй хөдөлмөрлөсөн боловч чи ер нь ямар нэгэн зүйл олж авсан уу? Чи өөрчлөгдсөн үү, эсвэл ямар нэг зүйл олж авсан уу? Хүнд бэрх туршлагынхаа хариуд чи цовдлогдсон Петр шиг, эсвэл цохигдож, агуу гэрлийг хүлээн авсан Паул шиг болсон уу? Чи эдгээр зүйлийг мэдэж байх ёстой. Би гичийн үрээс жаахан, элсний ширхэг шиг өчүүхэн чиний амийн талаар байнга ярьж, бодож байдаг юм биш. Ний нуугүй хэлэхэд, Би хүн төрөлхтнийг удирддаг. Гэхдээ Би, нэгэнтээ үзэн ядаж байсан ч дараа нь дахин олж авсан хүний амийг Өөрийн удирдлагын чухал хэсэг гэж үздэггүй. Урьдын ялгамж чанар чинь чухам юу болохыг, мөн түүнчлэн хэнд боол болж харьяалагддаг байснаа чи тодорхой мэдэж байх ёстой. Тиймээс Би Сатаныхтай адилхан хүмүүсийн нүүр царайг хүмүүсийг удирдах түүхий эд болгон ашигладаггүй, учир нь хүмүүс хэзээ ч үнэ цэнтэй зүйл байгаагүй. Анх та нарт хандаж байсан Миний хандлагыг та нар дурсаж, тухайн үед та нарыг дууддаг байсан, бодит ач холбогдолтой нэршлийг та нар санаж байх ёстой. Зүүдэг нэр хаяг чинь ул үндэсгүй биш гэдгийг чи мэдэх ёстой. Та нар Бурханд харьяалагдаж байгаагүй, харин аль эртнээс Сатанд олзлогдож, түүний гэрт үнэнч зарц болж үйлчилсэн гэдгээ бүгд мэдэж байгаа гэж Би бодож байна; түүнчлэн та нар аль эрт Намайг мартчихсан, учир нь та нар урт удаан хугацаанд Миний гэрийн гадна, муу

ёрын нэгний гарт байсан билээ. Миний авардаг хүмүүс бол Миний аль эрт урьдчилан тогтоосон, Надаар золин авруулсан хүмүүс юм, харин тэгэхэд ядуу дорд сүнснүүд та нарыг дүрмийг үл харгалзан хүмүүсийн дунд оруулсан. Та нар Давидын, эсвэл Иаковын гэрт харьяалагддаггүй, харин Харь үндэстний овгийн гишүүд болох Моабын гэрт харьяалагддаг гэдгээ мэдэж байх учиртай. Учир нь Би та нартай гэрээ байгуулаагүй, харин зөвхөн та нарын дунд ажил хийж, үг хэлж, та нарыг удирдсан. Миний цус та нарын төлөө урсаагүй; Би ердөө Өөрийн гэрчлэлийн төлөө та нарын дунд ажлаа явуулж байсан юм. Та нар үүнийг мэдээгүй гэж үү? Есүс та нарын өмнөөс цусаа урсган нас эцэслэсэнтэй Миний ажил үнэхээр адилхан гэж үү? Би та нарын төлөө тийм их доромжлол амссан нь анхнаасаа нэмэргүй хэрэг байсан юм. Огт нүгэлгүй Бурхан туйлын жигшмээр, балиар, хүн амьдрахад тохирохгүй гахай, нохойн ертөнцөд шууд ирсэн, гэсэн ч Би Өөрийн Эцгийн алдрын төлөө болон мөнхийн гэрчлэлийн төлөө энэ бүх харгис доромжлолыг мөн л тэвчсэн. Та нар биеэ авч явах байдлаа мэдэж, “баян, хүчирхэг гэр бүлд” төрсөн хүүхдүүд биш, харин ердөө Сатаны ядуу зүдүү үр хүүхэд гэдгээ харах учиртай. Та нар бас хүн төрөлхтнийг үндэслэгчид биш, мөн та нарт хүний эрх, эрх чөлөө ч байхгүй. Та нарт анхнаасаа хүн төрөлхтний ч, тэнгэрийн хаанчлалын ч ерөөл огт байгаагүй. Учир нь та нар хүн төрөлхтний хамгийн доод давхаргад байдаг бөгөөд Би та нарын ирээдүйг хэзээ ч бодож байгаагүй. Тиймээс, өнөөдөр та нарыг төгс болгох итгэл Надад байгаа нь Миний төлөвлөгөөний нэг хэсэг байсан хэдий ч энэ нь урьд өмнө үзэгдээгүй ажил юм, учир нь та нарын байр суурь хэтэрхий дорд агаад та нарт анхнаасаа хүн төрөлхтний хувь байгаагүй. Энэ нь яг нарийндаа хүмүүст өгсөн ерөөл биш гэж үү?

Миний авардаг хүмүүс бол ариусгалын ертөнцөөс Миний аль эрт чөлөөлсөн сүнснүүд, мөн аль эрт Миний зочилсон, сонгогдсон хүмүүс юм, учир нь тэд Намайг өөрсдийнх нь дунд дахин гарч ирэхийг маш их хүсэн тэмүүлсэн билээ. Би тэднийг хайрласан учраас тэд Намайг хайрлаж, цусаараа байгуулсан гэрээг минь өөрсдийн зүрх сэтгэлд сийлжээ. Тэд Намайг олон жил хайсаар ирсэн төөрсөн хурганuудтай адил бөгөөд тэд бол сайн; тиймээс Би тэднийг сайн израильчууд, хайр татам бяцхан тэнгэрэлчүүд гэж нэрлэдэг. Хэрвээ Би тэдний дунд байсан бол ийм доромжлолыг амсахгүй байх байв. Учир нь тэд Намайг аминаасаа ч илүү хайрладаг ба Би тэднийг бүх зүйлийн дундаас хамгийн гоё сайхан нь мэт хайрладаг. Яагаад гэвэл, тэд Надаар бүтээгдсэн бөгөөд Надад харьяалагддаг; тэд хэзээ ч Намайг мартаагүй. Тэдний хайр та нарынхаас давдаг бөгөөд та нар амиа хайрладгаас ч илүүтэйгээр тэд Намайг хайрладаг. Бяцхан цагаан тагтаанууд тэнгэрт захирагддаг шиг тэд Надад захирагддаг бөгөөд зүрх сэтгэлдээ Надад та нараас ч илүү дуулгавартай байдаг. Тэд Иаковын үр удам, Адамын үр хүүхдүүд, мөн Миний сонгосон хүмүүсийн дунд байдаг учраас, Би тэднийг маш удаан хугацаанд хайрласан—та нарыг хайрладгаасаа ч илүүтэйгээр хайрласан учраас ийм байдаг; харин та нар хэтэрхий тэрслүү, эсэргүүцэл чинь ийм ноцтой учраас та нар Намайг

дэндүү их дорд үзэж, Надад хэтэрхий хүйтэн хөндий хандаж, Намайг дэндүү бага хайрлаж, хэт их үзэн яддаг. Та нар Миний ажлыг басамжилж, Миний үйлдлүүдийг хэтэрхий их басамжилдаг. Тэднээс ялгаатай нь та нар Миний үйл хэргийг хэзээ ч эрхэмлэж байгаагүй. Харин ч та нар тэдгээрийг басамжилдаг ба нүд чинь яг Сатаных шиг түгшсэндээ улайдаг. Та нарын дуулгавартай байдал хаана байна вэ? Ёс жудаг чинь хаана байна? Хайр чинь хаана байна? Та нар өөрсдийнхөө дотор байгаа хайрын бүрэлдэхүүн хэсгийг хэзээ харуулсан юм бэ? Хэзээ та нар Миний ажлыг ноцтойгоор авч үзсэн юм бэ? Миний ирэхийг дэнслэн хүлээж, Намайг тэсэн ядан хүлээх зуураа асар ихээр зовж байгаа хайр татам тэнгэрэлчүүд өрөвдөлтэй еэ, учир нь Би тэднийг маш их хайрладаг билээ. Гэсэн хэдий ч, тэдэнтэй ямар ч хамаагүй хүний-бус ертөнцийг л Би өнөөдөр хардаг. Мөс чанар чинь аль хэдийн хөшүүн, мэдрэлгүй болсон гэж та нар бодохгүй байна уу? Та нар бол хайр татам тэнгэрэлчүүдтэй нэгдэхэд минь саад болдог өөдгүй амьтад гэж бодохгүй байна уу? Тэд Миний эргэн ирэхийг хэзээ хүлээхгүй байсан юм бэ? Надтай эргэн нэгдэхээ хэзээ хүлээхгүй байсан юм бэ? Надтай хамт сайхан өдрүүдийг өнгөрүүлж, хамт хооллох боломжтой байхыг тэд хэзээ хүлээхгүй байсан юм бэ? Та нар ер нь өнөөдөр юу хийж байгаагаа ухаарсан уу: дэлхий ертөнц даяар догшин ширүүн авирлаж; бие биенийхээ эсрэг хуйвалдаж; бие биенээ хууран мэхэлж; итгэл эвдэж, нууж далдлан, ичгүүр сонжуургүй авирлаж; үнэнийг үл мэдэж; шударга бус, ов мэхтэй үйлдэж; зусардан бялдуучилж; өөрсдийгөө үргэлж зөв, бусдаас илүү сайн гэж тооцон; биеэ тоож; уулын зэрлэг амьтан шиг хэрцгий, араатны хаан шиг бүдүүлэг авирладаг—эдгээр нь хүнд тохирох зан авир мөн үү? Та нар бол бүдүүлэг, бодлогогүй. Миний үгийг хэзээ ч эрхэмлээгүй, харин ч үл тоомсорлосон хандлага баримталсан. Ийм байвал амжилт, жинхэнэ хүний амьдрал, сайхан итгэл найдвар хаанаас ирэх юм бэ? Хэрээс хэтэрсэн төсөөлөл чинь чамайг үнэхээр барын амнаас аврах уу? Шатаж буй галаас чамайг үнэхээр аврах уу? Хэрвээ чи Миний ажлыг үнэлж баршгүй эрдэнэс гэж үнэхээр авч үзсэн бол ийм болтлоо доройтох байсан уу? Чиний хувь заяаг үнэхээр өөрчилж болохгүй юм гэж үү? Чи тийм харуусалтайгаар насан эцэслэхийг хүсэж байна уу?

ХҮНИЙ ТӨРӨЛХИЙН ЯЛГАМЖ ЧАНАР БОЛОН ҮНЭ ЦЭН ЯГ ЯМАРХУУ ВЭ?

Та нар шавар шавхайнаас салсан бөгөөд юу ч байлаа гэсэн, бузар заваан, Бурханы үзэн яддаг шаар шавхруун дундаас сонгогдсон. Та нар Сатанд харьяалагдаж байсан бөгөөд нэгэнтээ түүгээр гишгэлүүлж, гутаагдсан билээ. Тийм учраас та нарыг шавар шавхайнаас салсан гэж хэлсэн бөгөөд та нар огт ариун биш, харин ч аль эртнээс Сатаны хууран мэхлэлтийн бай байсаар ирсэн хүн-бус зүйлс юм. Энэ бол та нарт хамгийн их тохирох үнэлгээ мөн. Загас, сам хорхой зэрэг хорхой хүргэм

олзтой харьцуулахад та нар тогтоол ус, шавар шавхайнаас олдсон бохир заваан зүйлс юм, учир нь та нар ямар ч таашаалаар хангадаггүй. Шуудхан хэлэхэд, та нар бол нийгмийн доод давхаргын хамгийн дорд амьтад, гахай нохойноос ч дор. Ний нуугүй ярихад та нарыг ингэж нэрлэх нь хэтрүүлэг ч биш, дэгсдүүлэг ч биш; харин ч энэ нь асуудлыг хялбарчилдаг. Та нарт ийм байдлаар хандах нь үнэндээ хүндлэл үзүүлж байгаа хэрэг гэж ч хэлж болно. Хүн болохын хувьд та нарын хэрсүү ухаан, үг яриа, зан авир болон шавар шавхай доторх байр суурийг чинь оролцуулаад амьдралын чинь бүх тал “ер бусын” ялгамж чанартай гэдгийг чинь батлахад хангалттай.

СУРАЛЦДАГГҮЙ АГААД МЭДЛЭГГҮЙ ХЭВЭЭР ҮЛДДЭГ ХҮМҮҮС: ТЭД АРААТАН БИШ ГЭЖ ҮҮ?

Өнөөдрийн замаар алхахад чинь хамгийн тохиромжтой эрэл хайгуул юу вэ? Эрэл хайгуулдаа чи өөрийгөө ямархуу хүн гэж үзэх ёстой вэ? Шалгалт ч бай, зовлон бэрхшээл ч бай, эсвэл өршөөлгүй гэсгээлт, хараал ч бай, өнөөдөр чамд тохиолддог бүхэнд хэрхэн хандах ёстойгоо чи мэдэж авбал зохино. Энэ бүх зүйлтэй тулгараад чи тухай бүрд нь эдгээрийг анхааралтай эргэцүүлэх ёстой. Яагаад Би ингэж хэлдэг вэ? Учир нь эцсийн эцэст өнөөдөр чамд тохиолддог зүйл бол удаа дараа болдог богино хугацааны шалгалт юм; магадгүй чиний хувьд, эдгээр нь сэтгэлийн дарамт болдоггүй тул чи аливааг зөнд нь орхиж, ахиж дэвших эрэл хайгуулын чинь эрхэм нандин хөрөнгө гэж авч үздэггүй байх. Чи ямар бодлогогүй юм бэ! Маш их хайхрамжгүй болохоор чи энэхүү эрхэм нандин хөрөнгийг нүдний чинь өмнө хөвөх үүл мэт үзэж, ахин дахин нүүр нүдгүй буудаг энэхүү хатуу ширүүн цохилт буюу богинохон, чиний хувьд харваас жин багатай цохилтуудыг эрхэмлэдэггүй, харин ч тэдгээрийг үнэн сэтгэлээсээ авч үзэлгүй, хөндий хүйтнээр харж, зүгээр л тохиолдлын цохилт мэт авч үздэг. Чи үнэхээр биеэ тоосон! Ахин дахин ирдэг шуурга адил догшин ширүүн эдгээр дайралтыг чи зүгээр л хөнгөн хийсвэрээр үл тоомсорлодог; заримдаа бүр хүйтнээр инээмсэглэж, огт хэнэггүй илэрхийлэл харуулахад ч хүрдэг—учир нь чи яагаад ийм “золгүй явдал” амссаар байгаагаа ганц удаа ч бодож үзээгүй. Би хүнд дэндүү шударга бус ханддаг гэж үү? Би чамайг гоочлохыг ажил хэргээ болгодог гэж үү? Сэтгэлгээний чинь асуудал Миний дүрсэлсэн шиг ноцтой биш байж болох ч гаднах байдлаараа чи дотоод ертөнцөө аль хэдийн төгс дүрсэлсэн. Зүрх сэтгэлийн чинь гүнд нуугдсан цорын ганц зүйл бол бусдад бараг мэдэгдэхээргүй хараал зүхлийн бодлогогүй үг, уйтгар гунигийн үл ялиг ул мөр гэдгийг Би хэлэхийн ч хэрэггүй. Ийм шалгалтуудыг туулсан нь маш шударга бус санагддаг учраас чи харааж зүхдэг; шалгалтууд чамд дэлхий ертөнцийн хоосролыг мэдрүүлдэг учраас чи уйтгар гунигаар дүүрдэг. Удаа

дараагийн эдгээр цохилт болон сахилгажуулалтыг хамгийн шилдэг хамгаалалт гэж үзэхийн оронд чи Тэнгэрийн утгагүй төвөг чирэгдэл, эсвэл чамд тохирох залхаан цээрлүүлэлт гэж хардаг. Чи маш мэдлэггүй! Чи сайхан цаг хугацааг өршөөлгүйгээр харанхуйд хашдаг; гайхалтай шалгалт, сахилгажуулалтыг дайсны чинь дайралт гэж ахин дахин үздэг. Чи орчиндоо хэрхэн дасан зохицохоо мэддэггүй, дасан зохицохоор оролдохыг ч хүсдэггүй, учир нь чиний хувьд харгис, олон удаагийн энэ гэсгээлтээс чи ямар нэгэн зүйл олж авахыг хүсдэггүй. Чи эрж хайж, судалж шинжлэх ямар ч оролдлого хийдэггүй, зүгээр л хувь заяандаа буулт хийж, хувь заяа чинь хаашаа хөтөлнө, тийшээ явдаг. Хэрцгий балмад цээрлүүлэлт шиг санагддаг зүйл зүрх сэтгэлийг чинь өөрчлөөгүй, зүрх сэтгэлийг чинь ч эзэмдээгүй; харин ч зүрх сэтгэлийг чинь шархлуулдаг. Чи энэхүү “харгис гэсгээлтийг” энэ амьдралын чинь дайсан гэж л үздэг тул юу ч олж аваагүй. Чи өөрийгөө туйлын их зөвтгөдөг! Жигшүүртэй байснаасаа болоод л ийм шалгалтууд туулж байна гэж чи бараг боддоггүй; харин ч өөрийгөө тун хувьгүй хэмээн үздэг, түүнчлэн Намайг өөрийг нь үргэлж гоочилж байна гэж хэлдэг. Одоо юмс иймдээ тулсан байхад, Миний хэлдэг, хийдэг зүйлийн талаар чи үнэндээ хэр их мэддэг вэ? Чи өөрийгөө тэнгэрээс ялимгүй доогуур ч газраас хамаагүй өндөр, төрөлхийн авьяастан гэж бүү бод. Чи огтхон ч бусдаас илүү ухаантай биш—чамайг газар дээрх эрүүл ухаантай ямар ч хүнээс илүү гайхмаар тэнэг гэж ч хэлж болно, учир нь чи Миний үйлдлийг нэгд нэггүй нэвт харж чаддаг мэт, өөрийгөө хэтэрхий өндрөөр үнэлдэг, бусдаас дор гэж хэзээ ч үздэггүй. Үнэн хэрэгтээ чи эрүүл ухаан угаас дутмаг хүн, учир нь Миний хийхээр зорьж буй зүйлийг чи огт мэддэггүй, одоо юу хийж байгааг минь бүр ч мэддэггүй. Тиймээс, хүний амьдралын талаар өчүүхэн ч мэддэггүй мөртөө газраа хагалахдаа Тэнгэрийн ерөөлд найддаг хөгшин тариачинтай ч чи эн тэнцэхгүй гэж Би хэлсэн. Чи амьдралынхаа талаар нэг секунд ч бодож үздэггүй, нэр хүндийн талаар юу ч мэддэггүй, өөрийнхөө талаар бүр ч мэддэггүй. Чи туйлын “өндөр дээд!” Чам мэтийн ганган залуус, гоёмсог залуу хатагтай нарын төлөө Би үнэхээр санаа зовж байна: Бүр ч ширүүн шуурганы дайралтыг чи яаж тэсвэрлэж чадах юм бэ? Ганган залуус өөрсдийнхөө байгаа орчин нөхцөлийг огт хайхардаггүй. Тэдний хувьд энэ нь шалихгүй асуудал мэт харагддаг тул тэд энэ талаар юу ч боддоггүй бөгөөд тэдэнд сөрөг санагддаггүй, өөрсдийгөө дорд гэж ч боддоггүй; харин урьдын адил дэвүүрээ сэвэн, гудамжаар дэмий сэлгүүцсээр байдаг. Хэзээ ч суралцдаггүй, мэдлэггүй хэвээр үлддэг энэ “чухал хүмүүс” яагаад Би ер нь өөрсдөд нь ийм зүйл хэлдгийг огт мэддэггүй; царай нь уур уцаараар дүүрсэн тэд ердөө өөрсдийгөө хааш яаш шинжээд, дараа нь муу ёрын замаа өөрчлөлгүйгээр үргэлжлүүлдэг; Намайг орхимогцоо тэд дэлхий ертөнц дээр дахин улайран гүйж, дахиад ихэмсэглэн, луйвардаж эхэлдэг. Царайны чинь илэрхийлэл ямар хурдан өөрчлөгддөг билээ. Иймээс, чи ийм маягаар дахин нэг удаа Намайг мэхлэхээр оролдож байна—чи ямар увайгүй юм бэ! Тэр гоёмсог бяцхан хатагтай нар бүр ч инээдтэй. Миний яаралтай айлдваруудыг сонсож, байгаа орчин нөхцөлөө хараад тэд өөрийн эрхгүй

нулимс асгаруулж, эхэр татан уйлдаг бөгөөд үймээн тарьж байх шиг байдаг—хэчнээн зэвүүцмээр гээч! Биеийн хэмжээгээ ухаараад тэд орон дээрээ өнхрөн унаж, тэндээ хэвтээд, бараг эцсийн амьсгалаа авч буй мэт зогсолтгүй уйлдаг. Эдгээр үг хүүхдэрхүү зан, дорд байдлыг нь тэдэнд харуулж, дараа нь тэд сөрөг байдалд ихэд автан, нүднийх нь гэрэл үгүй болоод, Миний талаар гомдоллодог ч үгүй, Намайг үзэн яддаг ч үгүй, харин огт хөдөлгөөнгүй, сөрөг болохын зэрэгцээ сурч чадалгүй, мэдлэггүй хэвээр үлддэг. Намайг орхин явсныхаа дараа тэд наадан цэнгэдэг бөгөөд цангинасан инээд нь “Гүнжийн мөнгөн хонхны” чимээтэй адил байдаг. Тэд ямар эмзэг, өөрийгөө хайрлах хайраар ямар дутмаг юм бэ! Хүн төрөлхтний согогтой гологдол болох та бүхэн хүн чанараар хэчнээн дутмаг юм бэ! Та нар өөрсдийгөө хэрхэн хайрлахыг, эсвэл хэрхэн хамгаалахыг мэддэггүй, ямар ч эрүүл ухаангүй, үнэн замыг эрж хайдаггүй, жинхэнэ гэрлийг хайрладаггүй, түүнээс гадна өөрсдийгөө хэрхэн эрхэмлэхээ мэддэггүй. Та нарт удаа дараа өгсөн сургаалын минь тухайд бол, та нар үүнийг аль хэдийн сэтгэлийнхээ мухарт цөлөөд, тэр ч бүү хэл цаг нөхцөөх тоглоом мэт үзэхдээ тулсан. Тэгээд тэдгээрийг хувийн “хамгаалагч сахиусаа” гэж үргэлж үздэг. Сатан буруутгах үед чи зүгээр л залбирдаг; сөрөг байх үедээ гүн нойрт умбаж, аз жаргалтай байх үедээ хаа сайгүй гүйдэг; Намайг зэмлэх үед чи бөхийж, мэхийн ёсолдог; дараа нь Миний өмнөөс холдмогцоо тавласан янзтай инээдэг. Чи өөрийгөө бүхнээс дээр гэж боддог ч хамгийн биеэ тоосон нь гэж хэзээ ч боддоггүй, хэзээд ихэмсэг, маадгар, үгээр хэлэхийн аргагүй ихэрхүү байдаг. Суралцдаггүй, мэдлэггүй хэвээр үлддэг ийм “залуу эрчүүд”, “залуу хатагтай нар”, “ноёд”, “хатагтай нар” яаж Миний үгийг эрхэм нандин эрдэнэс мэт үзэж чадах юм бэ? Би чамаас дахиад асууя: Ийм удаан хугацаанд чи Миний үг болон ажлаас яг юу сурсан юм бэ? Чи хууран мэхлэхдээ улам чадварлаг болсон бус уу? Махан бие чинь илүү боловсорсон бус уу? Надад хандах хандлага чинь илүү хайхрамжгүй болсон бус уу? Би чамд шулуухан хэлье: Миний хийсэн энэ бүх ажил хулганых шиг зүрх зоригтой байсан чамайг илүү зоримог болгосон. Би хэтэрхий өршөөнгүй байж, хүчирхийлэл ашиглан махан биед чинь хэзээ ч хориг тулгаж байгаагүй учраас Надаас айж эмээх чинь өдөр ирэх бүр багасдаг. Магадгүй чиний харж байгаагаар, Би ердөө хатуу үг хэлж байгаа—гэвч ихэнхдээ Би чамд инээмсэглэсэн төрхөө харуулдаг бөгөөд чамайг нүүрэн дээр чинь бараг хэзээ ч шүүмжилж байгаагүй. Түүнчлэн, Би чиний сул талыг үргэлж уучилдаг бөгөөд үүнээс л үүдэн чи сайхан сэтгэлт тариачинд могой хэрхэн хандсаны адилаар Надад ханддаг. Хүн төрөлхтний дээд зэргийн ажиглах ур чадвар, хэрсүү ухааныг Би хэчнээн биширдэг гээч! Би чамд нэг үнэнийг хэлье: Өнөөдөр чамд хүндлэлийн зүрх сэтгэл байгаа юу, үгүй юү гэдэг нь тун бага хамаатай; Би тэр талаар түгшдэг ч үгүй, санаа зовдог ч үгүй. Харин Би чамд үүнийг ч бас хэлэх ёстой: Суралцдаггүй, мэдлэггүй хэвээр үлддэг “авьяаслаг хүн” чи эцэстээ өөрийгөө биширсэн, ялимгүй ухаалаг зангаасаа болж сүйрнэ—чи зовж, гэсгээгддэг нэгэн байх болно. Би чамайг дагалдан тамд зовж тэнэгтэхгүй, учир нь Би чамтай адилхан

төрлийнх биш. Чи бол Надаар хараагдсан атлаа Надаар заалгаж, авруулдаг бүтээл, Миний салахыг хүсдэггүй зүйл чамд огт байхгүй гэдгийг битгий март. Ажлаа хийх болгондоо Би ямар нэг хүн, үйл явдал, эд зүйлээр хэзээ ч хязгаарлагддаггүй. Хүн төрөлхтөнд хандах Миний хандлага, үзэл бодол үргэлж нэгэн хэвийн хэвээр байсан. Чи Миний удирдлагын хавсралт бөгөөд өөр ямар ч зүйлээс илүү онцгой байхааргүй учраас Би чамд тийм ч таатай ханддаггүй. Чамд өгөх Миний зөвлөгөө энэ: Чи Бурханы бүтээлээс цаашгүй гэдгээ цаг ямагт санаж байх ёстой! Чи Надтай хамт оршин байдаг байж болох ч ялгамж чанараа мэдэж байх ёстой; өөрийгөө хэтэрхий өндрөөр бүү бод. Би чамайг зэмлээгүй, эсвэл чамтай харьцаагүй, харин чамтай инээмсэглэн мэндэлсэн ч гэсэн, Надтай адил төрлийнх гэдгийг чинь нотлоход энэ хангалттүү. Чи үнэнийг эрэлхийлдэг хүмүүсийн нэг болохоос үнэн өөрөө биш гэдгээ мэдэж байх ёстой! Чи Миний үгийн дагуу өөрчлөгдөхөд үргэлж бэлэн байх ёстой. Чи үүнээс зугтаж чадахгүй. Энэ эрхэм нандин хугацаанд, ийм ховор боломж ирж байхад ямар нэгэн зүйл сурахаар хичээ гэж Би чамайг шавдуулж байна. Намайг бүү хуур; Намайг мэхлэхээр оролдон зусардах чинь Надад хэрэггүй. Намайг эрж хайх чинь ердөө ч Миний төлөө байдаггүй, харин өөрийн чинь төлөө байдаг!

ХЯТАДЫН СОНГОГДСОН ХҮМҮҮС ИЗРАИЛИЙН ЯМАР Ч ОВГИЙГ ТӨЛӨӨЛӨХ ЧАДВАРГҮЙ

Давидын гэр нь анх Еховагийн амлалт болон өвийг хүлээн авсан гэр бүл байсан юм. Энэ нь анхнаасаа Израилийн овгуудын нэг байсан бөгөөд сонгогдсон хүмүүст харьяалагдаж байв. Тухайн үед Ехова, Давидын гэрт харьяалагдаж байсан бүх иудей хүмүүс—тэрхүү гэрт төрсөн бүхэн—Өөрийнх нь өвийг хүлээн авах болно хэмээх хуулийг израильчуудад зориулан тогтоосон билээ. Тэд зуу дахин ихийг хүлээн авч, ууган хөвгүүдийн байр суурийг олж авах байсан юм; тухайн үедээ тэд бүх израильчуудын дундаас хамгийн их өргөгдсөн, Израилийн бүх гэр бүлийн дундаас хамгийн өндөр байр суурьтай хүмүүс байсан бөгөөд тахилчийн хувцас, титэм өмсөн сүмд Еховад шууд үйлчилдэг байв. Тухайн үед Ехова тэднийг итгэлтэй, ариун зарц нар хэмээн нэрлэсэн бөгөөд тэд Израилийн бусад бүх овгийн хүндлэлийг хүлээжээ. Тиймээс тухайн үед тэднийг бүгдийг нь хүндэтгэн эзэд мэт үздэг байлаа—энэ бүхэн нь Хуулийн эрин үе дэх Еховагийн ажил байв. Өнөөдөр тэд мөн л ийм маягаар сүмд Еховад үйлчилсээр байгаа тул өнө мөнхөд Еховагийн томилсон хаад юм. Тэд анхнаасаа Давидын гэрт харьяалагдаж байсан учраас хэн ч тэдний титмийг булаан авч чадахгүй, хэн ч тэдний үйлчлэлийг өөрчилж чадахгүй; энэ бол Еховагийн тэдэнд хайрласан зүйл юм. Та нар анхнаасаа Давидын гэрт харьяалагддаггүйн шалтгаан нь та нар Израилийн ардууд биш, харин Израилийн гаднах Харь үндэстнүүдэд харьяалагддаг. Түүнчлэн та нарын уг чанар Еховад шүтэн мөргөхийн төлөө биш, харин Түүнийг эсэргүүцэхийн төлөө байдаг тул

ялгамж чанар чинь Давидын гэрийн хүмүүсийнхээс угаасаа өөр бөгөөд та нар Миний өвийг хүлээн авах хүмүүс биш, зуу дахин ихийг авах хүмүүс бүр ч биш билээ.

Тухайн үед Израиль олон өөр гэр, олон өөр овогт хуваагдаж байсан ч бүгдээрээ сонгогдсон хүмүүс байлаа. Гэхдээ, ард түмнээ овгоор нь ангилж, Еховагийн өмнөх байр суурь болон хүн нэг бүрийн харьяалагддаг газар нутгаар нь ангилдгаараа Израиль бусад улс үндэстнээс өөр байдаг. Израилиас өөр орнуудад хүн өөрийгөө Давид, Иаков юм уу Мосегийн гэрт харьяалагддаг гэж санаандгүй хэлж чадахгүй. Энэ нь бодит баримтын эсрэг байх байсан—Израилийн овгуудыг бусад оронд хааш яаш буруугаар хамаатуулж болохгүй. Хүмүүс Давид, Абрахам, Есав гэх зэрэг нэрийг олон дахин буруугаар ашигладаг, эсвэл тэд: “Бид одоо Бурханыг хүлээн зөвшөөрлөө, иймээс бид бол Иаковын гэрийнх” гэж хэлдэг. Ийм зүйл хэлэх нь хүний үндэслэлгүй шалтаг төдий юм; энэ нь Еховагаас шууд ирдэггүй, Миний Өөрийн бодол санаанаас ч гардаггүй. Энэ нь гагцхүү хүний утгагүй үг юм! Давсалж дэгсдүүлсэн түүх урсгадаг уран илтгэгч шигээр хүмүүс өөрсдийгөө Давидын удам, эсвэл Иаковын гэр бүлийн нэг хэсэг хэмээн үндэслэлгүйгээр боддог бөгөөд ингэх нь зохистой гэж итгэдэг. Давидын гэрийн хүмүүсийг Ехова аль хэдийн томилсон бөгөөд Давид өөрийгөө хаанд өргөмжлөөгүй гэдгийг хүмүүс мэддэггүй гэж үү? Гэхдээ, өөрсдийгөө Давидын гэрийн үр удам хэмээн ичгүүргүйгээр зарладаг олон хүн бий—хүмүүс тун мунхаг! Үнэндээ Израилийн хэрэг явдал Харь үндэстнүүдтэй ямар ч хамаагүй—тэд бол огтоос хамааралгүй хоёр өөр зүйл юм. Израилийн хэрэг явдлуудыг зөвхөн Израилийн ард түмэнд л ярьж болно, харин Харь үндэстнүүдэд хамаагүй бөгөөд Харь үндэстнүүдийн дунд одоо хийгдэж буй ажил Израилийн ард түмэнтэй ямар ч хамаагүй юм. Миний одоо хэлж байгаа зүйл Харь үндэстнүүдийн талаар хэлдэг зүйлийг тодорхойлдог бөгөөд Израильд хийгдсэн ажлыг Харь үндэстнүүдийн дундах ажлын “хэв шинж” хэмээн үзэж болохгүй. Тэр нь Бурханыг хэтэрхий хуучинсаг харагдуулах бус уу? Харь үндэстнүүдийн дунд ажил түгж эхлэх үед л тэдний талаар ярьсан зүйлс юм уу тэдний үр дүн илчлэгдэнэ. Иймээс хүмүүс урьдын адилаар “Бид бол Давидын үр удам”, эсвэл “Есүс бол Давидын хүү” хэмээн хэлэх нь бүр ч утгагүй. Миний ажил ангилагдан хуваагддаг. Би “бугыг морь гэж нэрлэхгүй”; харин ч ажил дэс дарааллынхаа дагуу хуваагддаг.

ЕРӨӨЛҮҮДИЙГ ТА НАР ЮУ ГЭЖ ОЙЛГОДОГ ВЭ?

Энэхүү эринд төрсөн хүмүүсийг Сатан болон бузар чөтгөрүүд завхруулсан хэдий ч ийм завхрал тэдэнд бас дээд зэргийн аврал авчирсан бөгөөд энэ аврал нь уул талыг бүрхсэн Иовын мал хуй, хэмжээлшгүй их эд хөрөнгөөс ч агуу төдийгүй шалгалтынхаа дараа Иовын хүлээн авсан Еховаг нүдээр харах ерөөлөөс ч илүү агуу билээ. Иов үхлийн шалгалтыг туулсныхаа дараа л Еховагийн ярихыг сонсож, хуй салхин дундаас Еховагийн хоолойг сонссон. Гэсэн ч тэрээр Еховагийн царайг

хараагүй, Түүний зан чанарыг мэдээгүй. Иов ердөө махан биеийг таашаалаар хангадаг материаллаг эд хөрөнгө, ойр тойрны бүх хотын доторх хамгийн хөөрхөн хүүхдүүд болон тэнгэрийн тэнгэрэлчүүдийн хамгаалалтыг л олж авсан. Тэрээр Еховаг хэзээ ч хараагүй бөгөөд зөв шударга гэж нэрлэгдсэн хэдий ч Еховагийн зан чанарыг хэзээ ч мэдээгүй юм. Өнөөгийн хүмүүсийн материаллаг таашаал түр зуур хомсхон, гаднын ертөнцийн орчин нь дайсагнасан байдалтай байдаг гэж хэлж болох ч эрт дээр үеэс хүнд хэзээ ч илчлээгүй, үргэлж нууц байсаар ирсэн зан чанараа болон амбасын үеийн нууцаа Би, бүхнээс дорд боловч Өөрийн хамгийн агуу авралыг өгсөн хүмүүст илчилсэн. Түүнчлэн Би анх удаа эдгээр зүйлийг илчилсэн юм; Би ийм ажил урьд нь хэзээ ч хийж байгаагүй. Хэдий та нар Иовоос хамаагүй дорд боловч та нарын олж авсан, харсан зүйл түүнийхээс хол давсан. Та нар элдэв янзын зовлон туулж, янз бүрийн тарчлаан амссан хэдий ч тэр зовлон Иовын шалгалттай огтхон ч адилгүй; харин энэ нь өөрсдийн тэрслүү байдал, эсэргүүцэл болон Миний зөвт зан чанараас болж хүмүүсийн хүлээн авсан шүүлт, гэсгээлт юм; энэ бол зөвт шүүлт, гэсгээлт, хараал билээ. Нөгөө талаар, Иов нь Еховагийн агуу хайр, энэрлийг хүлээн авсан израильчуудын дундах зөв шударга хүмүүсийн нэг байв. Тэр ямар ч ёрын муу үйл үйлдээгүй, Еховаг эсэргүүцээгүй; харин ч Еховад итгэлтэйгээр үнэнч байлаа. Тэрээр зөв шударга байдлынхаа улмаас шалгалтуудад өртсөн ба Еховагийн итгэлт зарц байсан учраас ширүүн догшин шалгалтуудыг туулсан. Өнөөгийн хүмүүс бузар, зөв шударга бус байдлаасаа болж Миний шүүлт, хараалыг амсдаг. Иов мал хуй, эд хөрөнгө, зарц нар, үр хүүхэд, эрхэм нандин бүхнээ алдах үедээ амссан зовлонтой тэдний зовлон огт адилгүй хэдий ч тэд догшин ширүүн цэвэршүүлэлт, шатаалтыг амсдаг. Иовын туулснаас илүү ноцтой нь гэвэл, хүмүүс сул дорой байдгаас болж ийм шалгалтыг багасгах юм уу арилгадаггүй; харин энэ нь удаан явагдаж, тэдний амьдралын сүүлчийн өдрийг хүртэл үргэлжилнэ. Энэ бол шийтгэл, шүүлт, хараал юм; энэ нь өршөөлгүй шатаалт, үүнээс ч илүүтэйгээр хүн төрөлхтний зүй ёсны “өв залгамжлал” мөн. Энэ бол хүмүүсийн хүртэх учиртай зүйл бөгөөд энд Миний зөвт зан чанар илэрхийлэгддэг. Энэ бол мэдээжийн үнэн. Гэхдээ хүмүүсийн олж авсан зүйл одоо туулж буй зовлонгоос нь асар их давдаг. Та нарын туулдаг зовлон бол ердөө л мунхаг байдлаас чинь үүдсэн бүтэлгүйтэл, харин та нарын олж авдаг зүйл зовлонгоос чинь зуу дахин их билээ. Хуучин Гэрээн дэх Израилийн хуулийн дагуу бол, Намайг эсэргүүцдэг бүхэн, Намайг ил тод шүүдэг бүхэн, Миний замыг дагахын оронд Надад бузар тахилыг зоригтой өргөдөг бүхэн сүм дэх галаар гарцаагүй устгагдана, эсвэл сонгогдсон хүмүүсийн зарим нь тэднийг чулуугаар цохиж хөнөөнө, тэдний өөрсдийн овгийн үр удам төдийгүй бусад садан төрөл нь ч Миний хараалыг амсана. Ирэх амьдралдаа тэд эс чөлөөлөгдөж, Миний боолуудын боол болно, Би тэднийг харь үндэстнүүдийн дунд цөлж, тэд эх нутагтаа эргэн ирж чадахгүй байх болно. Тэдний үйлдэл, зан авирт үндэслэвэл, өнөөгийн хүмүүсийн туулсан зовлон израильчуудын амссан шийтгэл шиг төдийлөн ноцтой биш. Одоо

амсаж буй зүйл чинь залхаан цээрлүүлэлт юм гэж хэлдэг нь үндэслэлгүй биш, учир нь та нар үнэхээр хэрээс хэтэрсэн. Хэрвээ та нар Израильд байсан бол мөнхийн нүгэлтнүүдийн нэг болоод, аль хэдийн израильчуудаар хэдэн хэсэг тасчуулж, Еховагийн сүмд тэнгэрээс буух галд шатах байсан. Тэгвэл одоо та нар юу олж авсан юм бэ? Та нар юу хүлээн авч, юу эдэлсэн юм бэ? Би та нарт Өөрийн зөвт зан чанарыг илчилсэн ч хамгийн чухал нь хүн төрөлхтнийг золин аврахын төлөөх тэвчээрээ илчилсэн. Та нарт хийсэн бүхэн минь тэвчээрийн ажил юм; энэ нь Миний удирдлагын төлөө, түүнчлэн хүн төрөлхтний зугаа цэнгэлийн төлөө хийгддэг гэж хэлж болно.

Хэдийгээр Иов Еховагийн шалгалтыг туулсан ч тэр ердөө л Еховад шүтэн мөргөдөг зөв шударга хүн байсан юм. Тэдгээр шалгалтыг туулж байхдаа ч тэр Еховагийн талаар гомдоллоогүй, харин Түүнтэй учирснаа эрхэмлэн нандигнажээ. Өнөөгийн хүмүүс Еховагийн байгааг эрхэмлэдэггүйгээр үл барам, Түүний илрэлтийг голж, жигшиж, гомдоллож, доромжилдог. Та нар илүү ихийг олж авсан биш үү? Та нарын зовлон үнэхээр тийм их байсан гэж үү? Та нар Мариа, Иаков нараас илүү золтой байсан бус уу? Та нарын эсэргүүцэл үнэхээр тийм өчүүхэн байсан гэж үү? Миний та нараас шаардсан зүйл, Миний та нараас хүссэн зүйл дэндүү их, хэтэрхий олон байсан гэж үү? Миний уур хилэн шууд та нар дээр биш, Намайг эсэргүүцсэн израильчуудын дээр л буусан; та нарын олж авсан зүйл ердөө Миний өршөөлгүй шүүлт, илчлэл, мөн хайр найргүй догшин ширүүн цэвэршүүлэлт байсан. Тэгсэн хэр нь хүмүүс өчүүхэн төдий ч дуулгаваргүйгээр Намайг эсэргүүцэж, няцаасаар байдаг. Бүр Надаас өөрсдийгөө холдуулж, Намайг үгүйсгэдэг хүмүүс ч бий; тийм хүмүүс бол Мосег эсэргүүцсэн Кора, Датан нарын бүлэглэлээс дээрдэх юмгүй. Хүмүүсийн зүрх сэтгэл хэтэрхий хатуу цэвдэг, уг чанар нь дэндүү гөжүүд. Тэд хуучин арга замаа хэзээ ч өөрчилдөггүй. Тэд өдрийн хурц гэрэлд янхан мэт ил болсон гэж Би хэлдэг бөгөөд Миний үг “сонсоход ч эвгүй” байх хэмжээний хатуу байж, хүмүүсийн уг чанарыг ив ил болгодог—гэсэн ч тэд ердөө толгой дохин, хэдхэн нулимс унагаж, өөрсдийгөө хүчлэн багахан гунигладаг. Энэ бүхэн дуусмагц тэд уулын зэрлэг араатнуудын хаан мэт догширдог ба өчүүхэн төдий ч мэдрэмжгүй байдаг. Ийм зан чанартай хүмүүс Иовоос зуу дахин илүү зол завшаантай гэдгээ яаж мэдэх юм бэ? Эрин үеүдийн туршид бараг үзэгдээгүй, урьд нь хэний ч эдлээгүй ерөөлүүдийг эдэлж байгаагаа тэд яаж ухаарч чадах юм бэ? Шийтгэл агуулдаг ийм ерөөлүүдийг хүмүүсийн мөс чанар яаж мэдэрч чадах юм бэ? Шуудхан хэлэхэд, Миний ажлын үлгэр жишээ болж, Миний бүхий л зан чанар, бүх үйлдлийг гэрчилж чаддаг байж, Сатаны зовлон шаналлаас чөлөөлөгдөхийг л Би та нараас шаарддаг. Гэхдээ хүмүүс үргэлж Миний ажилд эгдүүцдэг бөгөөд үүнд зориуд дайсагнадаг. Ийм хүмүүс Израилийн хуулийг эргүүлэн авчирч, Израильд гаргасан уур хилэнгээ тэдэн дээр буулгахад Намайг турхирахгүй байж яаж чадах юм бэ? Хэдийгээр та нарын дунд Надад “дуулгавартай, хүлцэнгүй” хүн олон байгаа ч Корагийн бүлгийн адил хүмүүс бүр ч олон бий. Би бүрэн алдар суугаа олж авмагцаа тэнгэрийн галыг

ашиглан тэднийг үнс чандруу болтол шатаана. Би хүмүүсийг үгээрээ гэсгээхээ болино; харин Израилийн ажлыг хийхээсээ өмнө Би Намайг эсэргүүцсэн, аль эрт Надад таягдуулан хаягдсан “Корагийн бүлгийг” бүрмөсөн шатаана гэдгийг та нар мэдэх ёстой. Намайг таашаах боломж хүн төрөлхтөнд дахиж олдохгүй; харин тэд Миний уур хилэн, тэнгэрээс буух галыг л харна. Би бүх төрлийн хүмүүсийн янз бүрийн төгсгөлийг илчилж, тэднийг бүгдийг нь ангилан хуваана. Би тэрслүү үйл бүрийг нь анхааралдаа аваад Өөрийн ажлыг дуусгана, ингэснээр хүмүүсийн төгсгөл нь газар дээр байх үеийн Миний тогтоол, мөн түүнчлэн Надад хандах тэдний хандлагад үндэслэн шийдэгдэнэ. Тэр цаг ирэх үед тэдний төгсгөлийг өөрчилж чадах зүйл үгүй байх болно. Хүмүүс өөрсдийн төгсгөлийг илчлэг! Тэгээд Би хүмүүсийн төгсгөлийг тэнгэрлэг Эцэгт гардуулан өгнө!

БУРХАНЫ ТУХАЙ ЧИНИЙ ОЙЛГОЛТ ЮУ ВЭ?

Хүмүүс удаан хугацаанд Бурханд итгэсэн боловч тэдний ихэнх нь “Бурхан” гэдэг үгийг ойлгодоггүй, зүгээр л мунгинан дагадаг. Яагаад хүн чухам Бурханд итгэх ёстойг, эсвэл Бурхан чухам юу болох талаар тэдэнд ямар ч таамаг байдаггүй. Хэрвээ хүмүүс зөвхөн Бурханд итгэж, дагахаа мэддэг боловч Бурхан юу болохыг мэддэггүй, мөн Бурханыг таньдаггүй бол энэ нь асар том хошигнол биш гэж үү? Хүмүүс өдий хүрчхээд тэнгэрийн олон нууцыг нүдээр харж, хүний урьд өмнө хэзээ ч ойлгож байгаагүй гүн гүнзгий мэдлэгийн тухай ихээхэн сонссон ч гэсэн хүний хэзээ ч тунгаан бодож үзээгүй хамгийн энгийн үнэний талаар мэддэггүй. Зарим хүн: “Бид олон жил Бурханд итгэсэн. Бурхан юу болохыг бид яаж мэдэхгүй байх юм бэ? Энэ чинь биднийг дорд үзэж байгаа хэрэг биш гэж үү?” хэмээж болох юм. Гэвч бодит байдал дээр бол хэдийгээр өнөөдөр хүмүүс Намайг дагаж байгаа ч өнөөгийн ажлын талаар юу ч мэддэггүй бөгөөд Бурханы тухай нарийн төвөгтэй асуултуудыг бүү хэл, хамгийн илэрхий, хамгийн амархан асуултуудыг ч ухаарч чаддаггүй. Чиний үл тоомсорлодог, мэдэж чаддаггүй тэр бүх асуулт бол ойлгох хэрэгтэй хамгийн чухал асуулт гэдгийг мэдэх хэрэгтэй, учир нь чи зөвхөн олон нийтийг даган, өөрийгөө юугаар зэвсэглэх ёстой вэ гэдэгт ямар ч анхаарал хандуулдаггүй, мөн санаа тавьдаггүй. Яагаад Бурханд итгэх ёстойгоо чи үнэхээр мэддэг үү? Бурхан юу болохыг үнэхээр мэддэг үү? Хүн гэж юу болохыг үнэхээр мэддэг үү? Бурханд итгэдэг хүний хувьд, хэрвээ чи эдгээр зүйлийг ойлгож чадахгүй бол Бурханд итгэгчийн нэр хүндийг алдахгүй гэж үү? Өнөөдрийн Миний ажил бол хүмүүст мөн чанарыг нь ойлгуулж, Өөрийнхөө бүх үйл хэргийг ойлгуулж, Бурханы жинхэнэ нүүр царайг мэдүүлэх явдал юм. Энэ бол Миний удирдлагын төлөвлөгөөний төгсгөл, Миний ажлын сүүлчийн үе шат билээ. Тийм учраас Би та нарт амьдралын бүх нууцыг урьдчилан хэлж байна, ингэснээр та бүгд тэдгээрийг Надаас хүлээж авч чадах юм. Та нар хэтэрхий их дутагдалтай, хэтэрхий багыг эзэмшдэг учраас хүлээн

авч чадахгүй, дааж чадахгүй байсан ч гэсэн энэ нь эцсийн эрин үеийн ажил учраас урьд нь та нарын хэзээ ч хүлээн авч байгаагүй бүх амь-үнэнийг Би та нарт хэлэх ёстой. Харанхуй нөмрөх үед та нар замаасаа дахин гажаад, ёрын муу нэгний явуулгад автах вий гэсэндээ Би Өөрийн ажлыг дуусгаж, хийх учиртай ажлаа гүйцэлдүүлж, юу хийхийг даалгаж буйгаа та нарт бүрэн мэдэгдэхийг хүсдэг. Та нарын ойлгодоггүй олон зам, мэддэггүй олон асуудал бий. Та нар тун мэдлэггүй; Би та нарын биеийн хэмжээ болон дутагдлыг сайн мэднэ. Тиймээс, хэдийгээр та нарын ойлгож чадахгүй олон үг байдаг ч урьд нь та нарын хэзээ ч хүлээн авч байгаагүй энэ бүх үнэнийг Би та нарт бас л хэлмээр байна, учир нь одоогийн биеийн хэмжээгээрээ Миний төлөө гэрчлэлд зогсож чадах эсэхэд чинь Би санаа зовсоор байдаг. Би та нарыг дорд үзэж байгаа юм биш; та нар бүгдээрээ Миний албан ёсны сургалтыг хараахан туулаагүй адгууснууд бөгөөд та нарын дотор хэр их алдар байгааг Би яавч харж чадахгүй. Хэдийгээр Би та нар дээр ажиллахдаа асар их эрч хүч зарцуулсан боловч та нарт идэвхтэй хүчин зүйл бараг байхгүй мөртөө сөрөг хүчин зүйл хуруу дарам цөөн байдаг ба Сатанд шившиг авчирдаг гэрчлэл л болдог мэт санагддаг. Та нарт байгаа бусад зүйл бараг бүгдээрээ Сатаны хор. Та нар Надад аврагдахын аргагүй мэт харагддаг. Одоогийн нөхцөл байдалд Би та нарын янз бүрийн илэрхийлэл, биеэ авч явах байдлыг хардаг, тэгээд эцэст нь жинхэнэ биеийн хэмжээг чинь мэддэг. Тийм учраас Би та нарын төлөө санаа зовсоор байна: Өөрөө амьдралаа мэдэг гээд орхисон бол хүмүүс өнөөдрийнхөөсөө дээр байх байсан уу, эсвэл өнөөдрийнхтэй адилхан байх байсан уу? Та нар нялхамсуу биеийн хэмжээндээ сэтгэл зовохгүй байна уу? Та нар үнэхээр Израилийн сонгогдсон хүмүүс шиг байж, цаг үргэлж ганцхан Надад үнэнч байж чадах уу? Та нарын харуулдаг зүйл чинь эцэг эхээсээ төөрсөн хүүхдүүдийн дүрсгүйтдэг зан биш, харин эзнийхээ ташуураас хол байгаа амьтдаас гардаг зэрлэг догшин байдал юм. Та нарт бас бүгдэд нь байдаг сул тал, та нарын нийтлэг эмгэг болох уг чанараа та нар мэдэх ёстой. Тиймээс өнөөдөр Би та нараас Миний төлөөх гэрчлэлдээ бат зогсохыг л шаарддаг. Ямар ч нөхцөлд хуучин эмгэгээ дахин бүү сэдрээ. Хамгийн чухал зүйл бол гэрчлэл хийх явдал юм—энэ нь Миний ажлын гол цөм билээ. Зүүдэнд нь ирсэн Еховагийн илчлэлийг Мариа хүлээн авч, итгээд дуулгавартай дагасантай адилаар та нар Миний үгийг хүлээн авах ёстой. Зөвхөн энэ нь л ариун явдал гэж тооцогддог. Та нар Миний үгийг хамгийн их сонсдог хүмүүс учраас Надаар хамгийн их ерөөгдсөн хүмүүс юм. Би үнэ цэнтэй бүх эзэмшлээ та нарт өгч, та нарт бүхнийг хайрласан атал байр суурь чинь Израилийн ард түмнийхээс асар өөр; эгээ л тэнгэр газар мэт ялгаатай байдаг. Гэсэн ч тэдэнтэй харьцуулахад та нар хамаагүй илүү ихийг хүлээн авсан; тэд Миний илрэлтийг цөхрөн хүлээж байхад та нар Надтай хамт таатай өдрүүдийг өнгөрөөн, Миний баялгийг эдэлдэг. Ийм ялгаатай байж та нар хашхирч, Надтай маргалдаж, эд хөрөнгө булаалдах ямар эрхтэй юм бэ? Та нар ихийг олж авсан бус уу? Би та нарт маш ихийг өгсөн боловч хариуд нь Надад өгч байгаа зүйл чинь зүрх шимшрүүлсэн

уй гашуу, зовнил болон номхоршгүй эгдүүцэл, дургүйцэл байдаг. Та нар маш зэвүүн атлаа бас өрөвдөлтэй тул Өөрийн бүх дургүйцлийг дарж, та нарт ахин дахин эсэргүүцлээ илэрхийлэхээс өөр сонголт Надад байхгүй. Ажлын энэ хэдэн мянган жилийн туршид Би хүн төрөлхтөнд хэзээ ч эсэргүүцэл үзүүлээгүй, учир нь хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд та нарын дундах “заль мэх” л хамгийн их алдаршсан гэдгийг Би олж мэдсэн, тэр нь эртний алдарт өвөг дээдсийн чинь та нарт үлдээсэн нандин өв хөрөнгөтэй адил мэт байдаг. Хүнээс дор тэр гахай, нохойнуудыг Би хэчнээн их үзэн яддаг гээч. Та нар хэтэрхий мөс чанаргүй! Та нар хэтэрхий жудаггүй! Та нарын зүрх сэтгэл хэтэрхий хатуу! Хэрвээ Би ийм үг болон ажлыг израильчуудад аваачсан бол аль хэдийн алдрыг олж авах байлаа. Гэвч та нарын дунд бол энэ нь хүршгүй; та нарын дунд зөвхөн харгис хайнга байдал, үл тоомсорлол болон та нарын шалтаг л байдаг. Та нар дэндүү мэдрэмжгүй, дааНч үнэ цэнгүй!

Та нар өөртөө байгаа бүхнийг Миний ажлын төлөө зориулах ёстой. Надад ашиг тустай ажил хийх ёстой. Ойлгодоггүй бүхнийг чинь Би та нарт тайлбарлахыг хүсэж байна, ингэвэл та нар өөрсдөдөө дутагдаж байгаа бүхнийг Надаас олж авч чадна. Хэдий та нарын дутагдал тоолоход хэтэрхий олон боловч Би та нар дээр хийх ёстой ажлыг үргэлжлүүлэн хийж, та нарт сүүлчийн өршөөлөө хайрлахыг хүсэж байна, ингэснээр та нар Надаас ашиг тус хүртэж, та нарт байхгүй, мөн дэлхий дээр хэзээ ч харагдаж байгаагүй алдрыг олж авч болох юм. Би маш олон жил ажилласан боловч хэн ч, хэзээ ч Намайг мэдээгүй. Би өөр хэнд ч, хэзээ ч хэлээгүй нууцуудаа та нарт хэлэхийг хүсэж байна.

Хүмүүсийн дунд бол Би тэдний харж чадахгүй Сүнс, тэдний хэзээ ч харилцаж чадахгүй Сүнс байлаа. Газар дээрх ажлынхаа гурван үе шатнаас (дэлхий ертөнцийн бүтээл, золин аврал, сүйрэл) үүдэн Би хүмүүсийн дунд ажлаа хийхээр өөр өөр цаг үед (хэзээ ч илэрхий бишээр) тэдний дунд гарч ирдэг. Анх удаа хүмүүсийн дунд ирсэн минь Золин авралын эрин үед байсан. Мэдээж, Би иудей гэр бүлд ирсэн; тийм болохоор газар дээр ирсэн Бурханыг эхлээд харах хүмүүс нь иудейчүүд байв. Би энэ үе шатны ажлыг биечлэн хийсэн шалтгаан нь Өөрийн махбод болсон биеийг золин авралын ажилдаа нүглийн тахил болгон ашиглахыг хүссэн юм. Тиймээс Намайг эхлээд харах хүмүүс нь Нигүүлслийн эрин үеийн иудейчүүд байлаа. Энэ бол эхний удаа махбодоор ажилласан минь юм. Хаанчлалын эрин үед Миний ажил байлдан дагуулж, төгс болгохын төлөө байдаг учраас Би хариулах ажлаа дахин махбодоор хийдэг. Энэ бол хоёр дахь удаа махбодод ажиллаж байгаа минь юм. Ажлын сүүлчийн хоёр үе шатанд хүмүүсийн харилцдаг зүйл харагдашгүй, хүршгүй Сүнс биш, харин Сүнс махбодод биеллээ олсон хүн билээ. Тиймээс хүний нүдээр бол Би дахиад Бурханы ямар ч гадаад төрх, мэдрэмжгүй хүн болсон. Түүнчлэн, хүмүүсийн хардаг Бурхан зөвхөн эрэгтэй ч биш, бас эмэгтэй бөгөөд энэ нь хүмүүст хамгийн гайхмаар, адармаатай байдаг. Миний ер бусын ажил олон олон жилийн турш хадгалагдсан хуучин итгэл үнэмшлийг ахин

дахин нураасан. Хүмүүс мэл гайхдаг! Бурхан ердөө Ариун Сүнс, Сүнс, долоо дахин эрчимжсэн Сүнс, бүхнийг хамарсан Сүнс төдийгүй, мөн хүн—жирийн хүн, туйлын эгэл хүн юм. Тэр бол зөвхөн эрэгтэй ч биш, бас эмэгтэй. Тэд хоёулаа хүнээс төрсөн гэдгээрээ адилхан бөгөөд нэг нь Ариун Сүнснээс олдсон, нөгөө нь хүнээс төрсөн боловч Сүнснээс шууд гарсан гэдгээрээ адилгүй. Хоёулаа Бурханы махбод болох Тэд Эцэг Бурханы ажлыг гүйцэтгэдгээрээ адилхан бөгөөд нэг нь золин авралын ажил хийдэг, нөгөө нь байлдан дагуулалтын ажил хийдэг гэдгээрээ адилгүй. Хоёулаа Эцэг Бурханыг төлөөлдөг боловч нэг нь өгөөмөр сэтгэл, өршөөлөөр дүүрэн Золин Аврагч, харин нөгөө нь уур хилэн, шүүлтээр дүүрэн зөвт байдлын Бурхан билээ. Нэг нь золин авралын ажлыг эхлүүлдэг Дээд Командлагч, харин нөгөө нь байлдан дагуулах ажлыг гүйцэтгэдэг зөвт Бурхан юм. Нэг нь Эхлэл, нөгөө нь Төгсгөл. Нэг нь нүгэлгүй махбод, нөгөө нь золин авралыг гүйцээж, ажлыг үргэлжлүүлдэг махбод бөгөөд хэзээ ч нүгэлгүй. Хоёулаа нэг Сүнс, гэвч Тэд өөр өөр махбодод оршдог ба өөр өөр газарт төрсөн. Мөн Тэд хэдэн мянган жилээр тусгаарлагдсан. Тэгсэн хэр нь Тэдний бүх ажил харилцан нэгийгээ нөхдөг, хэзээ ч зөрчилддөггүй бөгөөд эн зэрэгцүүлэн ярьж болно. Хоёулаа хүн, гэхдээ нэг нь нялх хүү, харин нөгөө нь нярай охин. Энэ олон жилд хүмүүсийн харсан зүйл зөвхөн Сүнс, зөвхөн хүн, эрэгтэй хүн төдийгүй, бас хүний үзэлтэй нийцэхгүй олон зүйл байсан тул хүмүүс Намайг хэзээ ч бүрэн ойлгож чаддаггүй. Би оршин байдаг хэр нь хий хоосон мөрөөдөл мэт тэд Надад хагас итгэж, хагас эргэлзсээр байдаг, тийм учраас энэ өдрийг хүртэл хүмүүс Бурхан юу болохыг бас л мэдэхгүй хэвээр байгаа юм. Чи Намайг ганц энгийн өгүүлбэрээр товч дүгнэж үнэхээр чадах уу? Чи “Есүс бол Бурхан, Бурхан бол Есүс” гэж хэлж үнэхээр зүрхлэх үү? “Бурхан бол Сүнс, Сүнс бол Бурхан” гэж хэлэх зориг чамд үнэхээр бий юү? “Бурхан бол ердөө махбодоор хувцасласан хүн” гэж чи хэлж зүрхлэх үү? “Есүсийн дүр бол Бурханы агуу дүр мөн” гэж чи үнэхээр хэлж зүрхлэх үү? Чи Бурханы зан чанар болон дүрийг хэл ярианы чадвараараа нэгд нэггүй тайлбарлаж чадах уу? Чи “Бурхан эмэгтэй хүнийг биш, зөвхөн эрэгтэй хүнийг Өөрийн дүрээр бүтээсэн” гэж хэлж үнэхээр зүрхлэх үү? Хэрвээ чи ингэж хэлбэл Миний сонгосон хүмүүс дотор ямар ч эмэгтэй хүн байхгүй байх байсан бөгөөд хүн төрөлхтний дотор эмэгтэй хүний төрөл гэж бүр ч байхгүй байх байв. Одоо чи Бурхан юу болохыг үнэхээр мэдэх үү? Бурхан хүн үү? Бурхан Сүнс үү? Бурхан үнэхээр эрэгтэй юү? Миний хийхийг хүсдэг ажлыг зөвхөн Есүс гүйцэлдүүлж чадах уу? Хэрвээ чи Миний мөн чанарыг товчхон дүгнэхийн тулд дээр хэлснээс зөвхөн нэгийг нь л сонгох юм бол чи хэтэрхий мэдлэггүй үнэнч итгэгч юм. Хэрвээ Би ердөө ганцхан л удаа махбод болсон биеэр ажилласан бол та нар Намайг тодорхойлох байсан уу? Чи ганц хяламхийж хараад л Намайг нэвт шувт мэдэж үнэхээр чадах уу? Амьдралынхаа туршид үзэж амссан бүхнийхээ дүнд чи Намайг үнэхээр бүрэн дүүрэн дүгнэж чадах уу? Хэрвээ хоёр удаа бие махбодтой болохдоо Би адилхан ажил хийсэн бол та нар Надад хэрхэн хандах байсан бэ? Та нар Намайг загалмайд үүрд цовдлон орхих байсан уу? Бурхан чиний хэлдэг шиг тийм энгийн юм гэж үү?

Хэдийгээр та нарын итгэл маш чин сэтгэлийн боловч та нарын дундаас хэн нь ч Намайг бүрэн тайлбарлаж чадахгүй, хэн нь ч өөрсдийн хардаг бүх баримтыг бүрэн гэрчилж чадахгүй. Энэ талаар бодоод үз: Өнөөдөр та нарын ихэнх нь үүргээ хөсөр хаяад оронд нь махан биеийн араас хөөцөлдөж, махан биеийг ханган, махан биеийн ташаалд шунадаг. Та нар өчүүхэн үнэнийг эзэмшдэг. Тэгэхээр харсан бүхнээ гэрчилж яаж чадах юм бэ? Та нар Миний гэрчлэгчид байж чадна гэдэгтээ үнэхээр итгэлтэй байна уу? Хэрвээ нэг л өдөр чи өнөөдрийн харсан бүхнээ гэрчилж чадахгүй бол бүтээгдсэн зүйлийн чиг үүргээ алдсан байх болно, мөн чиний оршин тогтнол ямар ч утга учиргүй байна. Чи хүн байх үнэ цэнгүй байх болно. Чи хүн биш байх болно гэж хэлж ч болох юм! Би та нар дээр хэмжээлшгүй их ажил хийсэн, гэвч одоогоор чи юу ч сурахгүй, юу ч мэдэхгүй, үр ашиггүй ажиллаж байгаа учраас ажлаа өргөжүүлэх цаг минь ирэхэд чи бүлх залгисан мэт гөлрөн ширтэж, ямар ч нэмэргүй байх болно. Тэр нь чамайг бүх цаг үеийн нүгэлтэн болгохгүй гэж үү? Тэр цаг ирэхэд чи гүн гүнзгий харууслыг мэдрэхгүй гэж үү? Гутрал цөхрөлд живэхгүй гэж үү? Би сэлгүүцэж, уйдсандаа энэ бүх ажлыг хийж байгаа юм биш, харин хожмын ажлынхаа суурийг тавихын тулд хийж байгаа юм. Би мухардалд ороод, ямар нэг шинэ зүйл хийхээс өөр аргагүй болсон юм биш. Чи Миний хийдэг ажлыг ойлгох ёстой; энэ нь гудамжинд тоглож буй хүүхдийн хийдэг зүйл биш, харин Миний Эцэгийг төлөөлөн хийгддэг ажил юм. Би Өөрөө энэ бүхнийг ганцаараа хийж байгаа юм биш; харин Өөрийн Эцэгийг төлөөлдөг гэдгийг та нар мэдэх хэрэгтэй. Энэ зуур та нарын үүрэг бол зүгээр л дагах, дуулгавартай байх, өөрчлөгдөх болон гэрчлэх явдал юм. Та нар яагаад Надад итгэх ёстой вэ гэдгийг л ойлгох учиртай; энэ бол та нарын дор бүрнээ ойлгох ёстой хамгийн чухал асуулт мөн. Миний Эцэг Өөрийн алдрын төлөө, дэлхийг бүтээсэн мөчөөсөө л та бүгдийг Миний төлөө урьдчилан тогтоосон. Тэрээр Миний ажлын төлөө болон Өөрийнхөө алдрын төлөө л та нарыг урьдчилан тогтоосон билээ. Миний Эцэгээс болж та нар Надад итгэдэг; Миний Эцэг урьдчилан тогтоосон учраас л та нар Намайг дагадаг. Үүний алийг нь ч та нар өөрсдөө сонгосон юм биш. Та нар бол Намайг гэрчлүүлэх зорилгоор Миний Эцэгийн Надад өгсөн хүмүүс юм гэдгийг ойлгох чинь бүр ч чухал юм. Тэр та нарыг Надад өгсөн учраас та нар Миний өгдөг зам болон Миний заадаг зам, бас үгийг даган мөрдөх ёстой, учир нь Миний замыг даган мөрдөх нь та нарын үүрэг билээ. Энэ нь Надад итгэх итгэлийн чинь анхдагч зорилго юм. Тиймээс Би та нарт ингэж хэлдэг: Та нар бол ердөө л Миний замыг мөрдүүлэхийн тулд Миний Эцэгийн Надад өгсөн хүмүүс билээ. Гэсэн ч та нар зөвхөн Надад итгэдэг; та нар израиль гэр бүлээс гаралтай биш, харин эртний могойн төрөл учраас Минийх биш. Миний төлөө гэрчлэл хийхийг л Би та нараас шаардаж байна, гэхдээ өнөөдөр та нар Миний замаар алхах ёстой. Энэ бүхэн нь ирээдүйн гэрчлэлийн төлөө байдаг. Хэрвээ та нар зөвхөн Миний замыг сонсдог хүмүүс шиг л үйлдэх юм бол ямар ч үнэ цэнгүй байх бөгөөд Миний Эцэг та нарыг Надад өгсний ач холбогдол алдагдана. Та нарт хэлэх гэж Миний зүтгээд байгаа зүйл бол энэ: Та нар Миний замаар алхах ёстой.

ЖИНХЭНЭ ХҮН БАЙХЫН УТГА УЧИР

Хүнийг удирдах нь үргэлж Миний үүрэг байж ирсэн. Түүнчлэн хүнийг байлдан дагуулах нь дэлхийг бүтээж байхдаа Миний тогтоосон зүйл юм. Эцсийн өдрүүдэд Би хүнийг бүрэн байлдан дагуулна, хүн төрөлхтний дундах тэрслүү хүмүүсийг байлдан дагуулах нь Сатаныг ялсны минь нотолгоо гэдгийг хүмүүс мэдэхгүй байж магад. Гэвч Сатаны барьж авч, үр хүүхдээ болгосон, гэрийг нь харж ханддаг үнэнч зарцаа болгосон хүмүүсийг Би байлдан дагуулна гэдгээ Өөрийн дайсантай тулаанд орох үедээ түүнд аль эрт хэлсэн билээ. Байлдан дагуулахын анхдагч утга нь ялан дийлж, доог тохуу болгох юм. Израиль хэлэнд энэ нь бүрмөсөн ялж, сүйрүүлнэ, Намайг дахин эсэргүүцэх чадваргүй болгоно гэсэн утгатай. Гэвч өнөөдөр та нарын дунд бол байлдан дагуулах гэсэн утгаар хэрэглэгддэг. Миний ажлыг саатуулж, үймүүлж чадах нь байтугай, дахин Намайг эсэргүүцэх чадваргүй болтол нь хүн төрөлхтний ёрын муучуудыг бүрэн устгаж, бут цохих нь цаг ямагт Миний санаа зорилго байж ирсэн гэдгийг та нар мэдэх учиртай. Иймээс хүний хувьд энэ үг нь байлдан дагуулах гэсэн утгатай болсон билээ. Энэ нэр томьёо ямар ч утгатай байлаа гэсэн Миний ажил бол хүмүүсийг ялах явдал. Учир нь хүн төрөлхтөн Миний удирдлагад хавсралт болдог нь үнэн ч нарийндаа бол хүмүүс Миний дайсан гэдэг нь яриангүй. Тэд бол Надтай сөргөлдөж, дуулгаваргүй байдаг ёрын муучууд. Хүмүүс чухамдаа Миний хараасан ёрын муу нэгний үр удам. Хүмүүс бол чухамдаа Надаас урвасан тэргүүн тэнгэрэлчийн үр удам. Хүмүүс бол үнэндээ аль эрт Надад гологдсоноосоо хойш эвлэршгүй дайсан минь болсон диаволын залгамж халаа. Бүх хүн төрөлхтний дээр тэнгэр бүрхэн харанхуйлж, огтхон ч цэлмэх шинжгүй байх агаад хүний ертөнц түнэр харанхуйд автаж, улмаар тэнд амьдарч байгаа хүн нүднийхээ өмнө сунгасан гараа ч тэр, толгой өнгийлгөх үедээ нарыг ч олж харж чадахгүй байх ажээ. Хөл доорх зам нь шалбаагтай, хотгор хонхортой, тахир мурий нугачаатай; газар тэр аяараа хүүр цогцсоор бүрхээстэй. Харанхуй булан үхэгсдийн хүүрээр дүүрч, сэрүүхэн, сүүдэртэй буланд чөтгөр бөөнөөрөө үүрлэжээ. Хүний ертөнцийн хаа сайгүй чөтгөрүүд сүрэглэн ирж буцна. Элдэв янзын араатны үр сад бузар буртагт баригдчихаад ширүүн тулаанд орж, үүний дуу чимээ нь зүрхэнд айдас хуруулна. Ийм цаг үед, ийм дэлхий ертөнц, “газрын диваажинд” амьдралын жаргал цэнгэлийг эрж хайхын тулд хүн хаачдаг вэ? Амьдралын хүрэх газраа олохын тулд хаачих вэ? Сатаны хөлд эртнээс дэвслүүлсэн хүн төрөлхтөн анхнаасаа л Сатаны дүрд орсон жүжигчин байсан—хамгийн гол нь хүн төрөлхтөн Сатаны биелэл бөгөөд Сатанд гэрчлэл хийгч нотолгооны үүрэг гүйцэтгэдэг нь тов тодорхой. Ийм хүн төрөлхтөн, гажуудсан бөөн шаар шавхруу, хүний энэ завхарсан гэр бүлийн үр удам Бурханд гэрчлэл хийж яахан чадах билээ? Миний суу алдар хаанаас ирдэг вэ? Миний гэрчлэлийг хүн хаанаас нь ярьж эхэлж болох вэ? Учир нь хүн төрөлхтнийг аль эрт завхруулсан Миний дайсан, эрт үед бүтээж алдар суу, амьдран харуулалтаараа дүүргэсэн хүмүүсийг минь аль эрт авч бузарлачхаад

Миний эсрэг зогсож байна. Алдар сууг минь булааж, Сатаны муу муухай, мөн сайн, мууг мэдүүлэгч модны жимсний шүүсийг ихэд хольсон хорыг л хүнд шингээжээ. Анх Би хүн төрөлхтнийг бүтээсэн; хүн төрөлхтний өвөг дээдэс Адамыг бүтээсэн. Түүнд бие хаа, дүр төрх заяагдаж, тэрээр ид хав, амин чанараар бялхаж, Бурханы алдар суу түүнийг дагалдсан билээ. Бурхан хүнийг бүтээсэн алдар суут өдөр энэ байлаа. Дараа нь Адамын биеэс Еваг бүтээсэн нь мөн л хүний өвөг дээдэс байсан, улмаар бүтээсэн хүмүүс минь Миний амьсгалаар дүүрч, суу алдраар минь бялхаж байсан билээ. Адам анх гараас минь мэндэлсэн бөгөөд Миний дүрийн төлөөлөл байсан юм. Иймээс “Адам” гэдэг нь анхандаа Миний амин эрч хүч, алдар сууг шингээсэн, бие, дүртэй, сүнс болон амьсгалтай, Миний бүтээсэн оршихуй хэмээх утгатай байв. Тэр Намайг төлөөлж, Миний дүрийг авч, амьсгалыг минь хүртэх чадвартай, сүнс бүхий цорын ганц бүтээгдсэн зүйл байсан юм. Эхэндээ Ева Миний бүтээхээр тогтоосон, амьсгалыг хүртсэн хоёр дахь хүн байсан тул “Ева” гэдэг уг нь Миний амин чанараар дүүрэн, алдар сууг минь хүртсэн, алдрыг минь үргэлжлүүлэх бүтээгдсэн зүйл гэсэн утгатай байлаа. Адамаас гарсан тул Ева мөн л Миний дүртэй байсан, учир нь тэр Миний дүрээр бүтсэн хоёр дахь хүн билээ. “Ева” гэдэг нь анхандаа сүнс, мах, яснаас бүтсэн амьд хүн, мөн хүн төрөлхтний дундах Миний хоёр дахь гэрчлэл төдийгүй хоёр дахь дүр гэсэн утгатай байв. Тэд хүн төрөлхтний өвөг дээдэс, хүний ариун нандин эрдэнэс, анхнаасаа сүнстэй хүмүүс байсан юм. Гэвч хүн төрөлхтний өвөг дээдсийн үр удмыг ёрын муу нэгэн дэвсэлж, эрхэндээ оруулж, хүний ертөнцийг түнэр харанхуйд автуулж, улмаар тэднийг Миний оршин тогтнолд итгэхээргүй болгожээ. Бүр ч жигшүүртэй нь, ёрын муу нэгэн хүмүүсийг завхруулж, бүгдийнх нь дээр дэвсэлж байхдаа тэдэнд хайрласан алдар суу, гэрчлэл, амин чанар, тэдэнд өгсөн амьсгал, амь, мөн хүний ертөнц дэх бүх алдар суу, хүн төрөлхтөнд зарлагадсан амьдралын бүх эх булгийг минь харгисаар булаан авч байна. Хүн төрөлхтөн гэрэлд байхаа больж, хүмүүс Миний олгосон бүх зүйлийг алдсан бөгөөд Миний өгсөн алдар сууг хөсөр хаяжээ. Бүх бүтээгдсэн зүйлийн Эзэн гэдгийг минь тэд яахан хүлээн зөвшөөрч чадах билээ? Тэнгэр дэх оршин тогтнолд минь яаж итгэсээр байх билээ? Газар дээрх алдрын минь илэрхийллийг тэд яаж олж чадах билээ? Өвөг дээдэс нь хүндэлдэг байсан Бурханыг энэ ач зээ нар өөрсдийг нь бүтээсэн Эзэн хэмээн хүлээн авч яахан чадах билээ? Адам, Евад Миний хайрласан алдар суу, дүр, гэрчлэл, мөн хүн төрөлхтний оршин тогтнолыг тэтгэдэг Миний олгосон амийг хөөрхийлөлтэй энэ ач зээ нар ёрын муу нэгэнд өгөөмрөөр “бэлэглэсэн”; ёрын муу нэгний дэргэд байгаагаа огт хайхралгүй, бүх алдар сууг минь түүнд өгдөг. “Шаар шавхруу” гэх нэр томьёо үүнээс л үүдэлтэй бус уу? Ийм хүн төрөлхтөн, ёрын муу чөтгөрүүд, алхаж яваа үхдэлүүд, Сатаны дүрүүд, Миний дайснууд алдар сууг минь эзэмшиж яахан чадах билээ? Хүмүүсийн дунд оршдог алдар суу, гэрчлэл болон нэгэн цагт бүгд Минийх байгаад эрт цагт хүмүүст өгсөн бүхнээ Би эргүүлэн олж авна—хүн төрөлхтнийг Би бүрэн байлдан дагуулна. Гэвч бүтээсэн хүмүүс минь Миний дүр, алдар суу бүхий ариун хүмүүс байсан

гэдгийг чи мэдэх учиртай. Тэд Сатаных байгаагүй, түүнд дэвслүүлж ч яваагүй, Сатаны хорын өчүүхэн ч ул мөргүй, гагцхүү Миний илэрхийлэл байлаа. Иймээс Би Өөрийн гараар бүтээсэн зүйл, өөр этгээдийн харьяа бус, Өөрийн хайрладаг ариун хүмүүсийг л хүсэж байгаагаа хүн төрөлхтөнд хэлдэг. Түүнчлэн Би тэднийг таашааж, Өөрийн алдар суу хэмээн тооцно. Харин Сатаны завхралд өртөөд өнөөдөр Сатанд харьяалагдаж, Миний анхдагч бүтээл байхаа больсон хүн төрөлхтнийг Би хүсдэггүй. Хүний ертөнцөд буй алдар суугаа эргүүлэн олж авахыг Би зорьж буй тул Сатаныг ялсан алдрынхаа нотолгоо болгон хүн төрөлхтний дундаас амьд үлдэгсдийг бүрэн байлдан дагуулна. Гэрчлэлээ л Би Өөрийн биежилт, Өөрийн таашаалын бай болгодог. Миний хүсэл энэ билээ.

Хүн төрөлхтний хөгжлийн түүх хэдэн арван мянган жилийн тэртээгээс эхэлсэн авч анх Миний бүтээсэн хүн төрөлхтөн аль эрт доройтолд оржээ. Хүн төрөлхтөн Миний хүсдэг хүн төрөлхтөн байхаа больсон тул Миний нүдээр бол хүн төрөлхтөн хэмээн нэрлэгдэх эрхгүй болсон. Харин ч тэд Сатаны олзолсон хүн төрөлхтний хог шаар, Сатанд бариулж, нөмрөх хувцас нь болсон илжирсэн амьд хүүр билээ. Хүмүүс Миний оршин тогтнолд итгэдэггүй, Намайг ирж байхад ч угтан авдаггүй. Хүсэлтэд минь дурамжхан хариу үзүүлж, түр зуур буулт хийхээс биш амьдралын баяр гунигийг чин сэтгэлээсээ Надтай хуваалцдаггүй. Хүмүүс Намайг ойлгохын аргагүй гэж үздэг тул дурамжхан инээмсэглэж, эрх мэдэлтэнд тал засаж буй хандлагатай байдаг, учир нь хүмүүс Миний ажлыг огт мэддэггүй, өнөө үе дэх Миний хүслийг бүр ч мэддэггүй. Би та нартай илэн далангүй байя: Цаг нь ирэхээр Намайг шүтэн мөргөдөг хэн бүхний зовлон та нарынхыг бодвол тэвчихэд амар байх болно. Надад итгэх итгэлийн чинь хэмжээ үнэндээ Иовынхоос давдаггүй, иудейн фарисайчуудын итгэл ч та нарынхаас илүү байдаг тул галын өдөр ирэхэд та нарын зовлон Есүст зэмлүүлсэн фарисайчууд, Мосег эсэргүүцсэн 250 удирдагч, дүрэлзэх галд сүйрсэн Содомын зовлонгоос ч хүнд байх болно. Мосе хадыг цохиход Еховагийн хайрласан ус оргилсон нь түүний итгэлээс үүдэлтэй. Давид Ехова Намайг магтан лир хөгжим хөгжимдөж, зүрх сэтгэл нь баяр баяслаар дүүрдэг байсан нь түүний итгэлээс үүдэлтэй. Иов уул толгодыг бүрхсэн мал сүрэг, асар их эд хөрөнгөө алдан, бие нь яр шарханд баригдсан нь түүний итгэлээс үүдсэн. Ехова Миний дуу хоолойг сонсож, Ехова Миний алдар сууг харж чадсан нь ч түүний итгэлээс үүдэлтэй. Есүс Христийг Петр дагаж чадсан нь түүний итгэлээс улбаатай. Миний төлөө загалмайд цовдлогдож, алдар суут гэрчлэл хийж чадсан нь ч түүний итгэлээс улбаатай. Хүний Хүүгийн алдар суут дүрийг Иохан харсан нь түүний итгэлээс улбаатай. Эцсийн өдрүүдийн үзэгдлийг харсан нь түүний итгэлээс бүр ч их улбаатай. Харь үндэстний гэгдэх үй олон хүн Миний илчлэлийг олж авч, хүмүүсийн дунд ажлаа хийхээр махбодод эргэн ирсэн гэдгийг минь олж мэдсэн нь ч бас тэдний итгэлээс үүдэлтэй. Хатуу үгэнд минь цохиулдаг атлаа тэдгээрээс үүдэн тайтгарч, аврагддаг бүх хүн ч бас итгэлээсээ болж тэгдэг бус уу? Надад итгэдэг атлаа бэрхшээл туулдаг хүмүүс ертөнцөд мөн л гологдсон бус уу? Миний

үгийн гадна амьдарч, шалгалтад зовохоос зайлсхийдэг хүмүүс бүгд ертөнцөд туугдаж яваа бус уу? Энд тэнд найгах намрын навчис адил тэдэнд, тайтгаруулсан үг минь бүү хэл амрах газар ч үгүй. Миний гэсгээлт, цэвэршүүлэлт тэднийг дагадаггүй ч тэд газраас газарт туугдаж, тэнгэрийн хаанчлалын гаднах гудмаар тэнэж яваа гуйлгачид бус уу? Ертөнц үнэхээр чиний амрах газар гэж үү? Миний гэсгээлтээс зайлсхийснээр чи ертөнцөөс баяслын багахан ч болов инээмсэглэл олж авч үнэхээр чадна гэж үү? Зүрх сэтгэл дэх илэрхий хоосролоо зуурдын баяслаар далдалж үнэхээр чадах уу? Гэр бүлийнхнээ бүгдийг нь хуурч болох ч гэлээ Намайг чи хэзээ ч хуурч чадахгүй. Итгэл чинь дэндүү хомс тул өнөөг хүртэл чи амьдралаас ямар ч баяр баясал олж авахад хүчин мөхөстлөө. Амьдралынхаа хагасыг Миний төлөө чин сэтгэлээсээ зарцуулах нь дутуу дулимаг, ажилд нухлуулсан байдалтайгаар махан биеийн төлөө бүхий л амьдралаа үрж, хүн үүрч бараг чадахааргүй бүх зовлонг туулснаас дээр гэж чамайг Би шавдуулъя. Өөрийгөө тэгтлээ нандигнаж, Миний гэсгээлтээс зугтах ямар хэрэг байна? Зуурдын гэсгээлтээс минь нуугдаад гагцхүү мөнхийн ичгүүр, мөнхийн гэсгээлтэд унах ямар хэрэгтэй юм бэ? Үнэндээ Би Өөрийн хүслийг хэнд ч тулгадаггүй. Бүх төлөвлөгөөнд минь захирагдахад үнэхээр бэлэн хүн байвал түүнд Би муухай хандахгүй. Харин Иов Ехова Надад итгэдэг байсны адилаар бүх хүн Надад итгэхийг Би шаарддаг. Итгэл чинь Томасын итгэлээс давбал та нар сайшаалыг минь хүртэж, үнэнч байснаараа та нар жаргалыг минь олж, өөрсдийн цаг үед Миний алдар сууг гарцаагүй олно. Харин дэлхий ертөнцөд итгэж, диаволд итгэдэг хүмүүс яг л Содом хотын олон түмний адилаар зүрх сэтгэл нь цэвдэг болж, салхинд хийссэн элс нүдэнд нь орж, диаволын тахил аманд нь орж, балартсан оюун ухаан нь ертөнцийг булаан авсан ёрын муу нэгэнд аль эрт эзэмдүүлсэн байдаг. Тэдний бодол бараг тэр чигтээ эрт үеийн диаволд олзлуулсан. Иймээс хүн төрөлхтний итгэл салхинд хийсэж, Миний ажлыг анзаарах ч чадваргүй байдаг. Тэд ажилд минь хааш яаш хандаж, ширүүн дориунаар шинжлэх гэж үлгэн салган оролдохоос цаашгүй байдаг бөгөөд Сатаны хоронд аль эрт эзэмдүүлснээс нь энэ үүдэлтэй.

Хүмүүс Надаар бүтээгдэж, бүтээлийн минь арвин объектыг бүгдийг нь эдэлсэн тул хүн төрөлхтнийг Би байлдан дагуулна. Гэвч хүмүүс бас Намайг голсон; тэдний зүрх сэтгэлд Би байдаггүй, тэд Намайг оршин тогтнолынх нь садаа гэж үзээд, Намайг үнэхээр харсан атлаа мөн л голж, Намайг ялж болох бүх аргыг сэдэхээр тархиа гашилгадаг. Хүмүүс өөрсдөд нь нухацтай хандах, хатуу шаардлага тавихыг Надад зөвшөөрдөггүй, мөн зөв шударга бус байдлыг нь шүүж, гэсгээх боломж олгодоггүй. Тэд үүнийг сонирхох нь байтугай яршигтай гэж үздэг. Иймд Надаас идэж, ууж, найрладаг атлаа Намайг мэддэггүй хүн төрөлхтнийг авч, ялан дийлэх нь Миний ажил юм. Би хүн төрөлхтнийг аюулгүй болгоод, дараа нь Өөрийн тэнгэрэлчүүд, алдар сууг авч оршин суудаг газартаа буцна. Учир нь хүмүүсийн үйлдэл эртнээс сэтгэлийг минь шархлуулж, ажлыг минь хэдэн хэсэг нураасан юм. Би баяртайгаар алхан одохоосоо өмнө ёрын муу нэгний булаасан суу алдрыг

буцаан олж аваад, хүн төрөлхтөнд үргэлжлүүлэн амьдрах, “амар тайван, сэтгэл хангалуун амьдарч, ажиллах”, “тариалангийн талбайгаа хагалах” боломж олгохоор зорьдог бөгөөд тэдний амьдралд дахин оролцохгүй. Харин Би одоо ёрын муу нэгний гараас алдар суугаа бүрмөсөн буцаан олж авч, дэлхийг бүтээхдээ хүнд хайрласан алдар суугаа бүхэлд нь эргүүлэн авахаар зорьж байна. Газар дэлхий дээрх хүн төрөлхтөнд Би алдар суугаа дахин хэзээ ч хайрлахгүй. Учир нь хүмүүс алдар сууг минь хадгалж чадаагүйн дээр Сатаны дүрээр үүнийг сольсон. Хүмүүс Миний ирэхийг нандигнадаггүй, мөн Миний алдрын өдрийг ч өндрөөр үнэлдэггүй. Миний гэсгээлтийг хүртээд баярладаггүй, алдар сууг минь эргүүлэн өгөхийг бүр ч хүсдэггүй, ёрын муу нэгний хороос ангижрахыг ч хүсдэггүй. Хүн төрөлхтөн өнөөх л янзаараа Намайг хуурсан хэвээр, хүмүүс урьдын адил баяртайгаар инээмсэглэж, жаргалтай царайлсан хэвээр. Миний алдар суу орхин одсоны дараа хүн төрөлхтөнд нүүрлэх түнэр харанхуйн гүн гүнзгийг тэд мэддэггүй. Ялангуяа, Миний өдөр бүх хүн төрөлхтөн дээр ирэхдээ Ноагийн үеийн хүмүүсийнхээс ч илүү хатуурхахыг мэддэггүй, учир нь Миний алдар суу Израилийг орхих үед Израиль хэчнээн их харанхуйлсныг тэд мэддэггүй бөгөөд түнэр харанхуй шөнийг даван туулах ямар хэцүүг үүр цайх үед хүн мартдаг билээ. Нар дахин далд орж, хүн төрөлхтнийг харанхуй нөмрөх үед харанхуйд хүн дахин уйлж, шүдээ хавирна. Миний алдар суу Израилийг орхих үед зовлонт тэр өдрүүдийг тэсвэрлэх нь израильчуудад хэчнээн хэцүү байсныг та нар мартав уу? Одоо үе бол та нар Миний алдар сууг харах үе, мөн Миний алдрын өдрийг хуваалцах үе билээ. Миний алдар суу бузар булай газар нутгийг орхин одоход хүн харанхуйд уйлна. Одоо үе бол Миний ажиллах алдрын өдөр, мөн хүн төрөлхтнийг зовлонгоос гэтэлгэх өдөр, учир нь Би шаналан, гай зовлонгийн цаг үеийг тэдэнтэй хуваалцахгүй. Харин хүн төрөлхтнийг бүрэн байлдан дагуулж, хүн төрөлхтний ёрын муучуудыг бүрэн ялахыг л хүснэ.

ЧИ ИТГЭЛИЙН ТАЛААР ЮУ МЭДЭХ ВЭ?

Хүний дотор итгэлийн тухай эргэлзээтэй үг л байдаг, харин итгэл гэж юу болохыг хүн мэддэггүй, яагаад итгэдгээ бүр ч мэддэггүй. Хүн хэтэрхий багыг ойлгодог, мөн тэр өөрөө хэтэрхий учир дутагдалтай; тэр ердөө л бодлогогүй, мунхгаар Надад итгэдэг. Тэр итгэл гэж юу болох, мөн яагаад Надад итгэдгээ мэддэггүй хэдий ч хэнээрхэн итгэсээр байдаг. Миний хүнээс хүсдэг зүйл бол Намайг ийм байдлаар хэнээрхэн дуудаж, эсвэл Надад зорилгогүй байдлаар итгэх явдал биш. Учир нь, Миний хийдэг ажил хүнд Намайг харуулж, мэдүүлэхийн төлөө байдаг болохоос биш Намайг гайхан биширч, өөр нүдээр хараасай гэсэндээ биш юм. Би өмнө нь маш олон тэмдэг гайхамшиг үзүүлж, олон ер бусын зүйл үйлдсэн тул тухайн үеийн израильчууд Намайг гүнээ бахдан биширч, өвчтэйг анагааж, чөтгөрийг хөөх хосгүй чадварыг минь ихэд дээдэлсэн юм. Тухайн үеийн иудейчүүд

Миний анагаах хүч чадлыг чадварлаг агаад ер бусын гэж бодсон бөгөөд олон үйл хэргийг минь хараад тэд бүгд Намайг дээдлэн хүндэтгэж, бүх хүч чадлыг минь ихэд бахдан биширсэн. Тиймээс ер бусын зүйл үзүүлэхийг минь харсан хэн боловч Намайг ойр дагасан, улмаар өвчтэйг эдгээхийг минь харахаар мянга мянган хүн Намайг хүрээлсэн билээ. Би маш олон тэмдэг, гайхамшиг үзүүлсэн, гэвч хүн Намайг ердөө л чадварлаг эмч мэтээр үзсэн юм; Би бас тухайн үеийн хүмүүст сургаалын олон үг хэлсэн боловч тэд Надад ердөө л шавь нараасаа дээгүүрт тавигдах багш төдий хандсан! Өнөөдөр ч гэсэн хүмүүс Миний ажлын түүхэн тэмдэглэлийг харсныхаа дараа Намайг өвчтэйг анагаадаг агуу эмч, мэдлэггүй хүмүүсийн багш хэмээн тайлбарласаар байна. Мөн тэд Намайг өршөөлт Эзэн Есүс Христ хэмээн тодорхойлсон. Бичвэрүүдийг тайлбарладаг хүмүүс анагаах чадвараараа Надаас илүү байж болно, эсвэл одоо шавь нар нь багшаасаа давуу мэдлэгтэй болсон ч байж болно, гэвч нэр алдар нь дэлхий даяар цуурайтсан, асар алдартай ийм хүмүүс Намайг ердөө л шалихгүй эмч гэж дорд үздэг! Миний үйл хэрэг далайн эргийн элсэн ширхгээс ч олон бөгөөд Миний мэргэн ухаан Соломоны үр удмаас ч агуу атал хүмүүс Намайг шалихгүй эмч, мөн хүний үл таних багш л гэж боддог! Өөрсдийг нь эмчилнэ гэсэндээ л маш олон хүн Надад итгэдэг. Намайг хүч чадлаа ашиглан биеэс нь бузар сүнснүүдийг зайлуулах байх гэсэндээ, бас Надаас зүгээр л амар амгалан, баяр хөөр хүртэнэ гэсэндээ маш олон хүн Надад итгэдэг. Надаас илүү их материаллаг эд хөрөнгө шаардахын тулд маш олон хүн Надад итгэдэг. Мөн энэ амьдралаа амар амгалан өнгөрөөж, ирэх ертөнцөд эсэн мэнд, эрүүл саруул байхын тулд маш олон хүн Надад итгэдэг. Тамын зовлонгоос зайлсхийж, тэнгэрийн ерөөлийг хүлээж авахын тулд маш олон хүн Надад итгэдэг. Зөвхөн түр зуурын тав тухын төлөө маш олон хүн Надад итгэдэг хэдий ч ирэх ертөнцөд ямар нэг зүйл олж авахаар эрж хайдаггүй. Би Өөрийн уур хилэнг хүн дээр буулгаж, нэгэн цагт хүнд байсан баяр баясал, амар амгаланг булаан авах үед хүн эргэлзсэн. Би хүнд тамын зовлон өгч, тэнгэрийн ерөөлийг буцааж авах үед хүний ичгүүр нь уур хилэн болж хувирсан. Хүн өөрийг нь анагаагаач гэж Надаас гуйх үед Би ямар ч анхаарал тавилгүй, хүнд зэвүүцсэн; харин хүн ёрын муу эм болон хар шидийн замыг эрж хайхын тулд Надаас холдсон юм. Надаас нэхсэн бүхнийг нь хүнээс булаан авсны дараа хүн ул мөргүй алга болсон. Тиймээс, Намайг хэтэрхий их нигүүлсэл өгдөг учраас л, энэ нь маш их ашигтай байдаг учраас л хүн Надад итгэдэг гэж Би хэлдэг. Иудейчүүд Миний нигүүлслээс болж Надад итгэж, явсан газар бүрд минь Намайг дагасан. Эдгээр мэдлэг, туршлага хомс мунхаг хүмүүс Миний үзүүлсэн тэмдэг, гайхамшгийг олж харахыг л эрмэлзсэн. Тэд Намайг хамгийн агуу гайхамшгийг үзүүлж чаддаг иудей овгийн тэргүүн гэж үзсэн. Тиймээс хүмүүсээс чөтгөрийг хөөн зайлуулах үед тэдний дунд бөөн яриа дэгдэж, Намайг Елиа, Мосе гэцгээж, бүх эш үзүүлэгчээс хамгийн эртнийх нь, бүх эмчээс хамгийн агуу нь хэмээсэн юм. Би бол амь, зам, үнэн гэж Миний хэлснээс бусдаар хэн ч Миний оршихуй, ялгамж чанарыг мэдэж чадаагүй. Тэнгэр бол Миний Эцэгийн

амьдардаг газар гэж Намайг хэлснээс бусдаар бол Бурханы Хүү, Бурхан Өөрөө гэдгийг маань хэн ч мэдээгүй. Би бүх хүн төрөлхтөнд золин авралыг авчирч, хүн төрөлхтнийг гэтэлгэнэ гэж Намайг хэлснээс бусдаар бол хүн төрөлхтний Золин аврагч гэдгийг минь хэн ч мэдээгүй; хүмүүс Намайг энэрэнгүй, өршөөнгүй хүн гэж л мэддэг. Намайг Өөрөө Өөрийнхөө талаар бүхнийг тодорхой тайлбарлахаас нааш хэн ч Намайг мэдээгүй, мөн Намайг амьд Бурханы Хүү гэдэгт хэн ч итгээгүй. Хүн ийм л байдлаар Надад итгэж, ийм маягаар Намайг хуурах гэж оролддог. Хүн Миний талаар ийм үзэл бодолтой байж, Намайг яаж гэрчилж чадах билээ?

Хүн Надад итгэдэг боловч Надад гэрчлэл хийж чаддаггүй, Өөрийгөө таниулахаас минь өмнө Намайг гэрчилж ч чадахгүй. Хүмүүс зөвхөн намайг бүтээлүүд болон бүх ариун хүнээс давуу гэдгийг, Миний хийдэг ажлыг хүн хийж чадахгүй гэдгийг хардаг. Тиймээс иудейчүүдээс эхлээд өнөө үеийн хүмүүс хүртэл Миний суу алдарт үйл хэргийг харсан хэн боловч ердөө л Намайг сониучирхах сэтгэлдээ автсан байсан, харин ганц ч бүтээл Надад амаараа гэрчлэл хийж чадаагүй. Миний Эцэг л Надад гэрчлэл хийж, бүх бүтээлийн дунд Надад зам гаргаж өгсөн. Эс бөгөөс, Намайг яаж ч ажиллалаа гэсэн, бүтээлийн Эзэн гэдгийг минь хүн хэзээ ч мэдэхгүй байх байв, учир нь хүн Надаас авахыг л мэддэг ба Миний ажлаас болж Надад итгэдэг юм биш. Намайг гэм зэмгүй бөгөөд аль ч талаараа нүгэлтэн биш учраас, олон тооны нууцыг тайлбарлаж чаддаг учраас, олон түмнээс дээд нэгэн учраас, эсвэл хүн Надаас маш их ашиг тус хүртсэн учраас л хүн Намайг мэддэг хэдий ч цөөхөн хүн л Намайг бүтээлийн Эзэн гэдэгт итгэдэг. Ийм учраас хүн яагаад Надад итгэдгээ мэддэггүй гэж Би хэлдэг; хүн Надад итгэхийн зорилго, ач холбогдлыг мэддэггүй. Хүний бодит байдал нь учир дутагдалтай, ийм болохоор Надад гэрчлэл хийхэд бараг тохирдоггүй. Та нарын жинхэнэ итгэл тун өчүүхэн, олж авсан зүйл чинь хэтэрхий бага тул та нарт маш цөөхөн гэрчлэл байдаг. Түүнчлэн та нар хэтэрхий бага ойлголттой агаад тун учир дутагдалтай, ийм болохоор Миний үйл хэрэгт гэрчлэл хийхэд бараг тэнцэхгүй. Та нар үнэндээ нэлээд шийдэмгий, гэвч та нар Бурханы мөн чанарыг амжилттай гэрчилж чадна гэдэгтээ итгэлтэй байна уу? Та нарын туулсан, үзэж харсан зүйл өмнөх бүх үеийн эш үзүүлэгчид, ариун хүмүүсийнхээс давдаг, гэхдээ та нар өмнөх үеийн эш үзүүлэгчид болон ариун хүмүүсийн үгээс илүү агуу гэрчлэл өгч чадах уу? Одоо та нарт Миний хайрладаг зүйл Мосегийнхоос давж, Давидынхаас илүү гардаг, иймээс та нарын гэрчлэл Мосегийнхоос давж, үг чинь Давидынхаас илүү байхыг Би шаарддаг. Би та нарт зуу дахин ихийг өгдөг тул та нараас ч бас Надад тэр хэрээр эргүүлэн төл гэж шаарддаг. Би бол хүн төрөлхтөнд амь хайрладаг Нэгэн гэдгийг та нар мэдэх ёстой бөгөөд та нар Надаас амь хүлээн авдаг тул Надад гэрчлэл хийх ёстой. Энэ бол та нарын үүрэг, мөн Миний та нарт илгээдэг, Миний төлөө та нарын хийх учиртай зүйл юм. Би та нарт Өөрийн бүх алдрыг хайрлаж, сонгогдсон хүмүүс болох израильчуудын хэзээ ч аваагүй амийг хайрласан. Зүй нь бол та нар Надад гэрчлэл хийж, залуу насаа Надад зориулж, амиа өгөх учиртай. Миний алдар суугаа хайрласан хэн боловч

Надад гэрчлэл хийж, Миний төлөө амиа өгөх ёстой. Үүнийг Би аль эрт урьдчилан тогтоосон. Миний та нарт алдар суугаа хайрлаж байгаа нь та нарын ерөөл бөгөөд Миний алдрыг гэрчлэх нь та нарын үүрэг билээ. Та нар ерөөл хүртэхийн тулд л Надад итгэсэн бол Миний ажил ач холбогдол багатай байх бөгөөд та нар ч бас үүргээ биелүүлэхгүй байх болно. Израильчууд Миний өршөөл, хайр энэрэл болон агуу байдлыг л харсан бол иудейчүүд Миний тэвчээр болон золин авралыг л харсан. Тэд Миний Сүнсний ажлаас тун өчүүхнийг л ойлгосон; тэдний ойлголтын түвшин та нарын харсан, сонссоны арван мянганы нэг л байсан. Та нарын харсан зүйл тэдний ахлах тахилчдынхаас ч даван гардаг. Өнөөдөр та нарын ойлгосон үнэн тэднийхийг давдаг; та нарын өнөөдөр харсан зүйл Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үед ойлгож мэдэж байснаас ч илүү байдаг бөгөөд та нарын туулсан зүйл Мосе, Елиагийнхаас ч даван гардаг. Учир нь израильчууд зөвхөн Еховагийн хуулийг ойлгож, Еховагийн барааг араас нь л харсан юм; иудейчүүд Есүсийн золин авралыг л ойлгож, Есүсийн хайрласан нигүүлслийг л хүлээн авсан бөгөөд иудей овгийн гэр доторх Есүсийн дүрийг л харсан билээ. Өнөөдөр та нар Еховагийн алдар, Есүсийн золин аврал болон Миний өнөөдрийн бүх үйл хэргийг хардаг. Түүнчлэн та нар Миний Сүнсний үгийг сонсож, Миний мэргэн ухааныг ухамсарлаж, Миний гайхамшгийг мэдэж авч, Миний зан чанарын талаар олж мэдсэн. Би бас та нарт удирдлагын төлөвлөгөөгөө бүгдийг нь ярьсан. Та нарын харсан зүйл элэгсэг, өршөөнгүй Бурхан төдийгүй, мөн зөвт байдал бүрдсэн Бурхан билээ. Та нар Миний гайхамшигт ажлыг харж, уур хилэн, сүр жавхлангаар дүүрэн болохыг минь ч мэдсэн. Цаашлаад та нар израилийн гэрт догшин уур хилэнгээ буулгасныг минь мэдэх ба өнөөдөр энэ нь та нар дээр ирсэн. Та нар Исаиа, Иохан нараас ч илүүтэйгээр Миний тэнгэр дэх нууцуудыг ойлгосон; та нар өмнөх үеийн бүх ариун хүнээс илүүгээр Миний хайр татам, эрхэм байдлыг мэддэг. Та нар Миний үнэн, зам, амийг төдийхнийг хүлээн авсан хэрэг бус, харин Иоханыхаас ч агуу үзэгдэл, илчлэлийг хүлээн авсан юм. Та нар илүү олон нууцыг ойлгож, Миний үнэн төрхийг харсан; та нар Миний шүүлтийг илүү их хүлээн авч, Миний зөвт зан чанарыг илүү их мэдсэн. Иймээс та нар эцсийн өдрүүдэд төрсөн хэдий ч, та нарын ойлголт урьд үе, өнгөрсөн үеийнхнийхтэй адил, та нар бас өнөөдрийн зүйлсийг туулсан бөгөөд энэ бүгдийг Би биечлэн хийсэн билээ. Би та нарт дэндүү ихийг өгч, та нар ч Надаас ихийг харсан болохоор та нараас Миний шаарддаг зүйл хэрээс хэтэрсэн юм биш. Тиймээс, өмнөх үеийн ариун хүмүүст хандан Намайг гэрчлээч гэж Би та нараас хүсдэг, энэ бол Миний зүрх сэтгэлийн цорын ганц хүсэл билээ.

Эхлээд Миний Эцэг Надад гэрчлэл хийсэн боловч Би илүү агуу алдрыг хүлээн авч, бүтээгдсэн зүйлсийн амнаас гэрчлэлийн үг сонсохыг хүсдэг—иймээс та нараар үүргийг чинь гүйцэтгүүлэх гэсэндээ Би та нарт бүхнээ зориулж, хүмүүсийн дундах ажлаа төгсгөл болгодог. Та нар Надад яагаад итгэдгээ ойлгох ёстой; хэрвээ зүгээр л Миний шавь юм уу өвчтөн болж, эсвэл тэнгэр дэх ариун хүмүүсийн минь нэг болохыг хүсдэг бол Намайг дагаж байгаа чинь утга учиргүй байх болно. Ийм

байдлаар Намайг дагах нь зүгээр л хий дэмий хичээл зүтгэл байх байсан; ийм байдлаар Надад итгэх нь ердөө л өдөр хоногоо дэмий нөхцөөж, залуу насаа үрэн таран хийж байгаа хэрэг байх байсан. Тэгээд эцэст нь та нар юу ч хүлээн авахгүй. Энэ нь хий дэмий хөдөлмөр байх бус уу? Би иудейчүүдийн дундаас аль эрт явж одсон, Би хүний эмч эсвэл тэднийг анагаагч эм байхаа ч больсон. Би хүний хүссэнээр дөрлүүлж, нядлуулах ачлагын амьтан байхаа больсон; харин ч хүнийг шүүж, гэсгээн, хүнд Өөрийгөө мэдүүлэхээр хүмүүсийн дунд ирсэн юм. Нэгэн цагт Би золин авралын ажил хийсэн гэдгийг чи мэдэх ёстой; нэг үе Би Ехова байсан хэдий ч хожим нь Есүс болсны адилаар нэгэнтээ Би Есүс байсан боловч үүрд Есүс хэвээр үлдэж чадахгүй. Би хүн төрөлхтний Бурхан, бүтээлийн Эзэн боловч үүрд Есүс юм уу Ехова хэвээр байж чадахгүй. Би хүний хувьд эмч гэж тооцогддог нэгэн байсан, гэхдээ Бурхан бол ердөө л хүн төрөлхтнийг эмчилдэг эмч гэж тодорхойлж болохгүй. Иймээс хэрвээ чи Надад итгэхдээ хуучны үзэл бодлыг баримталбал юунд ч хүрэхгүй. “Бурхан хүнд хэчнээн хайртай гээч; Тэр намайг эдгээж, хүнд ерөөл, амар амгалан, баяр хөөр өгдөг. Бурхан хүнд хэчнээн сайн гээч; Түүнд итгэх л юм бол бид мөнгө, эд баялгийн талаар санаа зовох хэрэггүй …” хэмээн чи энэ өдөр Намайг яаж ч магтлаа гэсэн, Би анхны ажлаа тасалдуулж бас л чадахгүй. Өнөөдөр чи Надад итгэвэл зөвхөн алдрыг минь хүлээн аваад зогсохгүй, Надад гэрчлэл хийх эрхтэй болох бөгөөд бусад бүх зүйл хоёрдугаарт тавигдана. Үүнийг чи тодорхой мэдэх ёстой.

Одоо чи Надад яагаад итгэдгээ үнэхээр мэдэх үү? Миний ажлын зорилго болоод ач холбогдлыг чи үнэхээр мэдэх үү? Үүргээ үнэхээр мэдэх үү? Миний гэрчлэлийг үнэхээр мэдэх үү? Чи Надад зүгээр л итгэдэг боловч Миний алдар болон гэрчлэл чамаас харагддаггүй бол Би чамайг аль эрт таягдан хаячихсан. Их мэдэгчид бол харин Миний нүдэнд бүр ч том өргөс, гэрт маань тэд Миний замын садаа л байдаг, тэд бол Миний ажлаас бүрмөсөн шигшигдэх өчүүхэн ч хэрэггүй, ямар ч үнэ цэнгүй үрийн сүүлнүүд бөгөөд Би тэднийг аль эртнээс жигшсэн юм. Миний уур хилэн ихэнхдээ гэрчлэлгүй хүмүүс дээр бууж, Миний саваа тэднээс ер холдож байгаагүй. Би аль эрт тэднийг муу ёрын нэгний гарт шилжүүлсэн бөгөөд тэдэнд Миний ерөөл огтхон ч байхгүй. Цаг нь ирэх үед тэдний гэсгээлт мунхаг эмэгтэйчүүдийнхээс илүү гашуун байх болно. Одоо Би Өөрийн хийх үүрэгт ажлаа л хийж байгаа; Би эдгээр үрийн сүүлийн хамтаар бүх буудайг багцалж бооно. Энэ бол Миний одоогийн ажил юм. Намайг шигших үед эдгээр үрийн сүүл бүгд шигшигдэнэ, тэгээд буудайн үр тариаг агуулахад хурааж, шигшигдсэн үрийн сүүлийг үнс нурам болтол нь шатаахаар галд хийх болно. Одоо Миний ажил бол зүгээр л бүх хүнийг багцлан боох буюу бүрэн байлдан дагуулах явдал юм. Дараа нь Би бүх хүний төгсгөлийг илчлэхийн тулд шигшиж эхлэх болно. Иймээс чи одоо Намайг яаж сэтгэл хангалуун байлгахыг болон Надад итгэх зөв замд яаж орохыг мэдэх ёстой. Би чиний одоогийн үнэнч зан, дуулгавартай байдал, одоогийн хайр болон гэрчлэлийг л хүсдэг. Энэ мөчид чи гэрчлэл гэж юу болох, хайр гэж юу

болохыг мэдэхгүй байсан ч гэсэн өөрт байгаа бүхнээ Надад авчирч, өөртөө байгаа цорын ганц үнэт эрдэнэс болох үнэнч зан, дуулгавартай байдлаа Надад өгөх ёстой. Хүний үнэнч зан, дуулгавартай байдал бол Миний Сатаныг ялсан гэдгийн, түүнчлэн хүнийг Би бүрэн байлдан дагуулсан гэдгийн гэрчлэл гэдгийг чи мэдэх ёстой. Чи Надад итгэхдээ Надад гэрчлэл хийж, өөр хэнд ч биш Надад үнэнч байж, эцсээ хүртэл Надад дуулгавартай байх үүрэгтэй. Ажлынхаа дараагийн алхмыг эхлэхээс минь өмнө чи Надад хэрхэн гэрчлэл хийх вэ? Надад чи яаж үнэнч, дуулгавартай байх вэ? Чи өөрийн чиг үүрэгт бүх үнэнч байдлаа зориулах уу, эсвэл зүгээр л бууж өгөх үү? Чи Миний зохицуулалт бүрд (үхэл, сүйрэл байсан ч гэсэн) захирагдахыг илүүд үзэх үү, эсвэл Миний гэсгээлтээс зайлсхийхийн тулд замын хагасаас зугтах уу? Надад гэрчлэл хийж, Надад үнэнч, дуулгавартай байг гэсэндээ Би чамайг гэсгээдэг. Мөн одоогийн гэсгээлт нь Миний ажлын дараагийн алхмыг нээж, ажлыг саадгүй урагшлуулахын төлөө байдаг. Тиймээс чамайг ухаалаг байж, өөрийн амь болоод оршин тогтнолын ач холбогдлыг ямар ч үнэ цэнгүй атга шороо мэт үзэхгүй байхыг Би зөвлөж байна. Миний ирэх ажил яг ямар байхыг чи мэдэх үү? Ирэх өдрүүдэд Миний яаж ажиллахыг, Миний ажил хэрхэн өрнөхийг чи мэдэх үү? Чи Миний ажлыг мэдэрч туулж байгаагийнхаа ач холбогдлыг төдийгүй, Надад итгэх итгэлийнхээ ач холбогдлыг мэдэх хэрэгтэй. Би маш их ажил хийсэн, чиний бодсон шиг замынхаа хагаст больж яаж чадах билээ? Би ийм өргөн цар хүрээтэй ажил хийсэн; яаж үүнийгээ үгүй хийж чадах билээ? Үнэхээр ч Би энэ эрин үеийг дуусгавар болгохоор ирсэн. Энэ бол үнэн, гэвч үүнээс гадна Би шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажлыг эхлүүлж, хамгийн гол нь хаанчлалын сайн мэдээ түгээх гэж байгааг чи мэдэх ёстой. Тиймээс одоогийн ажил нь зөвхөн эрин үеийг эхлүүлж, ирэх цагийн сайн мэдээг түгээж, ирээдүйд эрин үеийг төгсгөл болгох суурийг тавихын төлөө юм гэдгийг чи мэдэх хэрэгтэй. Миний ажил чиний боддог шиг тийм ч энгийн биш, чиний итгэдэг шиг ямар ч үнэ цэнгүй, утга учиргүй ч биш. Тиймээс Би чамд бас л ингэж хэлэх ёстой: Чи Миний ажилд амиа зориулах учиртай бөгөөд цаашлаад өөрийгөө Миний алдрын төлөө зориулах ёстой. Надад гэрчлэл хийхийг чинь Би удаан хүсэн хүлээсэн, Миний сайн мэдээг түгээхийг чинь бүр ч удаан хүсэн хүлээсэн. Чи Миний зүрх сэтгэлд байгаа зүйлийг ойлгох учиртай.

УНАЖ БУЙ НАВЧИС ҮНДЭС РҮҮГЭЭ БУЦАХАД ЧИ ӨӨРИЙН ХИЙСЭН ЁРЫН МУУ БҮХЭНДЭЭ ХАРАМСАНА

Та нарын дунд хийсэн ажлыг минь та нар бүгд нүдээрээ харж, Миний хэлсэн үгийг өөрсдөө сонсож, та нарт хандах хандлагыг минь бүгд мэдсэн тул Би яагаад энэ ажлыг та нарт хийж байгааг мэдэх ёстой. Би та нарт үнэнээр нь хэлье, та нар бол эцсийн өдрүүд дэх байлдан дагуулалтын ажлын минь хэрэгсэл, Харь

үндэстнүүдийн дунд Миний ажлыг өргөжүүлэх багаж зэвсэг төдийхөн юм. Харь үндэстнүүдийн дунд Өөрийн ажлыг илүү сайн өргөжүүлж, Өөрийн нэрийг түгээхийн тулд, өөрөөр хэлбэл, Израилийн гаднах аливаа үндэстнүүдийн дунд түгээхийн тулд Би та нарын зөвт бус, бохир заваан байдал, эсэргүүцэл, тэрслүү байдлаар дамжуулан ярьдаг. Ингэснээр Миний нэр, Миний үйл хэрэг, Миний дуу хоолой Харь үндэстнүүд даяар тархаж, улмаар Израилийн бус тэр бүх үндэстэн Надаар байлдан дагуулагдаж, Намайг шүтэн мөргөж, Израиль болон Египет газар нутгийн гаднах Миний ариун газрууд болж болох юм. Миний ажлыг өргөжүүлэх нь үнэндээ байлдан дагуулах ажлыг минь өргөжүүлэх, Миний ариун газрыг өргөжүүлэх явдал билээ; энэ нь газар дээрх Миний тулах цэгийн өргөжилт юм. Та нар бол Миний байлдан дагуулдаг Харь үндэстнүүдийн дундах бүтээл төдий гэдгээ тодорхой мэдэж байх ёстой. Анх та нарт байр суурь ч байгаагүй, ашиглуулах үнэ цэн ч байгаагүй бөгөөд ямар ч хэрэггүй байсан. Би бүх газар нутгийг байлдан дагуулах загвар болгож, бүх газар нутгийг байлдан дагуулах “лавлах материал” болгохын тулд овоолсон өтөг бууцнаас өтнүүдийг өргөж гаргасан учраас л та нар Надтай холбоо тогтоож, одоо Надтай хамт цугларах хувьтай болсон. Дорд байр сууриас чинь болж Би та нарыг байлдан дагуулалтын ажлынхаа загвар, үлгэр дуурайл болгон сонгосон юм. Зөвхөн энэ шалтгааны улмаас л Би та нарын дунд ажиллаж, үг хэлдэг ба та нартай хамт амьдарч, түр оршин суудаг. Өөрийн удирдлагаас л болж, мөн овоолсон өтөг бууцан дундах өтнүүдийг туйлын их зэвүүцдэгээсээ болж Би та нарын дунд үг хэлж байгаа ба хилэгнэх хэмжээнд очсоныг та нар мэдэх ёстой. Та нарын дунд ажиллаж байгаа минь Ехова Израильд ажиллаж байсантай огтхон ч адилгүй бөгөөд ялангуяа Есүсийн Иудейд хийсэн ажилтай адилгүй. Би асар их тэвчээртэйгээр үг хэлж, ажилладаг ба уур хилэнтэйгээр, мөн шүүлттэйгээр энэ доройтсон хүмүүсийг байлдан дагуулдаг. Ехова Өөрийн ардуудыг Израильд удирдаж байсантай энэ огт адилгүй. Израиль дахь Түүний ажил хоол хүнс, амийн ус хайрлахын төлөө байсан бөгөөд Өөрийн ардуудыг хангаж байхдаа Тэрээр хайр, энэрлээр дүүрэн байлаа. Өнөөдрийн ажил нь сонгогдоогүй, хараагдсан үндэстэн дунд хийгддэг. Тэнд элбэг дэлбэг хоол хүнс байдаггүй, цангаа тайлах амийн ус ч байдаггүй, элбэг арвин эд материалын хангамж бүр ч байдаггүй; тэнд зөвхөн арвин их шүүлт, хараал, гэсгээлтийн хангамж л байдаг. Овоолсон өтөг бууцанд амьдардаг энэ өтнүүд нь Израильд Миний хайрласан шиг уул толгодыг бүрхсэн хонь мал, асар их эд баялаг, газар нутаг даяарх хамгийн хөөрхөн хүүхдүүдийг олж авахад огт тэнцэхгүй. Орчин үеийн Израиль Миний ард түмэнд нь өгдөг хонь мал, алт мөнгөн зүйлсийг тахилын ширээн дээр өргөж, хуулийн дор Еховагийн шаардаж байсан аравны нэгийг даван гарсан тул Би тэдэнд бүр ч ихийг—хуулийн дор Израилийн хүртсэнээс зуу дахин ихээс ч илүүг өгсөн. Израильд Миний өгсөн зүйл Абрахамын олж авсан бүхнээс давсан, мөн Исаакын олж авсан бүхнээс давсан билээ. Би Израилийн гэр бүлийг үржүүлж, олшруулна, Израилийн ард түмнээ газар дэлхий даяар тараана. Миний ерөөж, халамжилдаг хүмүүс бол мөн л Израилийн

сонгогдсон хүмүүс буюу Надад бүх зүйлээ зориулдаг, Надаас бүх зүйлийг олж авсан хүмүүс юм. Тэд Намайг оюун санаандаа хадгалдаг учраас дөнгөж төрсөн хурга, тугалаа Миний ариун тахилын ширээн дээр тахил болгодог бөгөөд Миний эргэн ирэхийг хүлээсэндээ саяхан мэндэлсэн ууган хөвгүүдээ ч өргөн барих хэмжээнд өөрсдөдөө байгаа бүхнийг Миний өмнө өргөдөг. Тэгвэл та нар яадаг вэ? Та нар Миний уурыг хүргэж, Надаас юм шаардаж, Надад өргөл өргөдөг хүмүүсийн тахилыг хулгайлдаг ба Надад халдаж байгаагаа мэддэггүй; тиймээс та нар харанхуй дахь уйлаан болон шийтгэлийг л хүртдэг. Та нар олон удаа Миний уурыг хүргэсэн бөгөөд нэлээд олон хүн эмгэнэлт төгсгөлтэй учирч, аз жаргалтай гэр орон нь эзгүй булш болох хэмжээнд Би Өөрийн дүрэлзсэн галыг доош цутгасан. Энэ өтнүүдэд зориулсан эцэс төгсгөлгүй уур хилэн л Надад байдаг бөгөөд тэднийг ерөөх санаа зорилго байхгүй. Өөрийн ажлын төлөө л Би та нарыг тусгайлан үзэж, өргөсөн ба асар их доромжлолыг тэвчиж, та нарын дунд ажилласан. Эцгийн минь хүслийн төлөө байгаагүй бол Би овоолсон өтөг бууцан дотор эргэлдэж байдаг өтнүүдтэй хамт нэг гэрт амьдарч яахан чадах билээ? Би та нарын үйлдэл, үг бүхнийг туйлаас жигшдэг бөгөөд ямартай ч та нарын бохир заваан, тэрслүү байдлыг бага зэрэг “сонирхдог” учраас энэ нь Миний үгийн асар их цуглуулга болсон. Эс бөгөөс Би та нарын дунд удаан хугацаагаар яавч үлдэхгүй байх байсан. Тиймээс Би та нарт ердөө л өрөвдөж, хөөрхийлсөн хандлагаар ханддаг; Надад та нарыг гэх ганц дусал ч хайр байхгүй гэдгийг та нар мэдэх ёстой. Надад ердөө та нарыг тэвчих тэвчээр л байгаа, учир нь Би үүнийг Өөрийнхөө ажлын төлөө л хийдэг. Би бохир заваан, тэрслүү байдлыг “түүхий эд” болгон сонгосон учраас л та нар Миний үйл хэргийг харсан; эс бөгөөс Би энэ өтнүүдэд Өөрийн үйл хэргийг яавч илчлэхгүй байх байсан юм. Би та нар дээр дурамжхан ажилладаг ба Израильд хийсэн ажлаа дуртайяа, мэрийн хийсэнтэй минь огтхон ч адилгүй. Би Өөрийгөө хүчлэн та нарын дунд үг хэлэнгээ уураа барьж байна. Хэрвээ илүү агуу ажлын минь төлөө байгаагүйсэн бол ийм өтнүүдийг байнга харахыг Би яаж тэвчиж чадах юм бэ? Миний нэрийн төлөө байгаагүйсэн бол Би аль хэдийн хамгийн өндөрт гарч, энэ өтнүүдийг овоолсон өтөг бууцтай нь хамт үнс нурам болтол шатаах байлаа! Миний суу алдрын төлөө байгаагүйсэн бол нүдний минь өмнө толгойгоо сэгсрэн Намайг илт эсэргүүцэхийг энэ муу ёрын чөтгөрүүдэд Би яаж зөвшөөрч чадах юм бэ? Өөрийн ажлыг өчүүхэн төдий ч саад бартаагүйгээр төвөггүй хэрэгжүүлэхийн төлөө байгаагүйсэн бол Намайг дурааараа хүчирхийлэхийг өт-шиг энэ хүмүүст зөвшөөрч яаж чадах юм бэ? Израилийн тосгон дахь зуун хүн Намайг эсэргүүцэхийн тулд ийнхүү боссон бол хэдий тэд Надад тахил өргөсөн ч гэсэн, бусад хотын хүмүүс хэзээ нэгэн цагт дахин тэрслэхээс сэргийлэхийн тулд Би тэднийг устгаж, газрын гаваар оруулах байсан юм. Би бүхнийг залгигч гал бөгөөд халдахыг тэвчдэггүй. Хүмүүсийг бүгдийг нь Би бүтээсэн учраас Миний хэлсэн, хийсэн юуг ч хүн дуулгавартай дагах ёстой ба тэрсэлж болохгүй. Миний ажилд хошуу дүрэх эрх хүмүүст байхгүй, Миний ажил болон Миний үгийн юу зөв, юу буруу болохыг задлан

шинжлэхэд тэд бүр ч тохирохгүй. Би бол бүтээлийн Эзэн бөгөөд бүтээгдсэн зүйлс Намайг хүндлэх зүрх сэтгэлээр Миний шаарддаг бүхнийг биелүүлэх ёстой; тэд Надад учирлахаар оролдох ёсгүй, ялангуяа эсэргүүцэх ёсгүй. Би Өөрийн эрх мэдлээр ард түмнээ засагладаг бөгөөд Миний бүтээлийн хэсэг болох бүх хүн Миний эрх мэдэлд захирагдах ёстой. Хэдийгээр өнөөдөр та нар Миний өмнө зоригтой, давилуун байж, Миний зааж сургадаг үгэнд дуулгаваргүй хандаж, ямар ч айдсыг мэддэггүй ч тэрслүү байдлыг чинь Би зөвхөн тэвчээрээр хариулдаг; шалихгүй жаахан өтнүүд овоолсон өтөг буцан дахь хог шороог хөдөлгөснөөс болоод Би уурсаж, ажилдаа нөлөөлөхгүй. Эцгийнхээ хүслийн төлөө Би зэвүүцэж, үзэн яддаг бүх зүйлийнхээ үргэлжилсэн оршин тогтнолыг тэвчдэг агаад бүх айлдвар маань дуусах хүртэл, мөн Өөрийн эцсийн мөчийг хүртэл ийнхүү тэвчинэ. Санаа бүү зов! Би нэргүй өттэй ижил түвшинд очиж чадахгүй, мөн ур чадварынхаа хэмжээг чамтай харьцуулахгүй. Би чамайг үзэн яддаг ч тэвчиж чадна. Чи Надад дуулгаваргүй ханддаг ч Эцгийн минь Надад амласан, чамайг гэсгээх өдрөөс минь зугтаж чадахгүй. Бүтээгдсэн өтийг бүтээлийн Эзэнтэй харьцуулж болно гэж үү? Намар цагт, унаж буй навчис үндэс рүүгээ буцдаг; чи “эцгийнхээ” гэр лүү буцаж, Би Эцгийнхээ хажууд буцан очно. Намайг Эцгийн минь энхрий зөөлөн хайр дагалдаж, чамайг эцгийн чинь дэвслэлт дагана. Надад Миний Эцгийн алдар байх болно, чамд эцгийн чинь ичгүүр байна. Чамд хань болгохын тулд Би удаан хугацаанд барьж байсан гэсгээлтээ ашиглана, чи хэдэн арван мянган жилийн турш завхарсаар ирсэн хуршсан махан биеэрээ Миний гэсгээлттэй тулгарна. Чамд хийсэн, тэвчээр дагалдсан үгийн ажлаа Би дуусгасан байх болно, чи Миний үгэн дэх гай гамшгийг туулах үүрэг гүйцэтгэж эхэлнэ. Би асар ихээр баярлан хөөрч, Израильд ажиллана; чи цурхиран уйлж, шүдээ хавиран, шавар шавхай дунд амьдарч, насан эцэслэнэ. Би анхдагч хэлбэрээ эргүүлэн олж аваад, чамтай хамт бузар заваанд үлдэхээ болино, харин чи анхдагч үзэшгүй муухай байдлаа эргүүлэн олж аваад, овоолсон өтөг бууцыг нүхлэн амьдарсаар байна. Миний ажил болон үг дуусах үед энэ нь Миний хувьд баяр хөөртэй өдөр байх болно. Эсэргүүцэл, тэрслүү байдал чинь дуусах үед энэ нь чиний цурхиран уйлах өдөр байх болно. Би чамайг өрөвдөхгүй, чи Намайг дахин хэзээ ч харахгүй. Би чамтай ярилцахаа болино, чи Надтай дахин хэзээ ч тааралдахгүй. Би тэрслүү байдлыг чинь үзэн ядна, чи Миний хайр татам байдлыг санана. Би чамайг цохиж, чи Намайг дурсан санана. Би баяртайяа чамаас салж одно, чи Надад өртэйгээ мэднэ. Би чамайг дахин хэзээ ч харахгүй, харин чи Надад үргэлж найдлага тавина. Чи одоогоор Намайг эсэргүүцдэг учраас Би чамайг үзэн ядна, харин Би одоо чамайг гэсгээдэг учраас чи Намайг үгүйлэн санана. Би чамтай хамт амьдрахыг хүсдэггүй боловч үүнийг чи гашуунаар хүсэн эрмэлзэж, үүрд уйлна, учир нь чи Надад хийсэн бүхэндээ харамсана. Чи тэрслүү байдал болон эсэргүүцэлдээ харуусаж, харамссандаа бүр нүүрээ газарт наан, Миний өмнө унаад, Надад ахин хэзээ ч дуулгаваргүй хандахгүй хэмээн тангараглана. Гэхдээ чи зүрх сэтгэлдээ ганцхан Намайг хайрлах боловч Миний дуу хоолойг хэзээ ч сонсож чадахгүй. Би чамайг өөрөөсөө ичихэд хүргэнэ.

Одоо Би, чиний өөгшүүлсэн махан бие Намайг аргалж хуурах гэж байгааг харж байгаа бөгөөд чамд зүгээр л бага зэрэг анхааруулга өгч байгаа ч чамд “үйлчлэхийн” тулд гэсгээлт ашиглахгүй. Чи Миний ажилд ямар үүрэг гүйцэтгэдгээ мэдэх ёстой, тэгвэл Би сэтгэл хангалуун байх болно. Үүнээс цааших асуудлууд дээр хэрвээ чи Намайг эсэргүүцвэл, Миний мөнгийг зарцуулбал, Ехова Надад зориулсан тахилыг идвэл, өтнүүд та нар нэг нэгнээ хазвал, эсвэл нохой шиг амьтад та нар тэмцэлдэж, өөр хоорондоо хүч хэрэглэвэл—Би алийг нь ч анхаарахгүй. Та нар өөрсдийгөө ямархуу зүйл болохоо л мэдэж байх хэрэгтэй ба тэгвэл Миний сэтгэл ханана. Энэ бүхнээс гадна, хэрвээ та нар нэг нэг рүүгээ зэвсэг далайж, үгээрээ өөр хоорондоо тэмцэлдэхийг хүсэж байвал тэгж болно; тийм зүйлсэд хөндлөнгөөс оролцох хүсэл Надад байхгүй, хүмүүсийн хоорондох хэрэг явдал Надад ямар ч хамаагүй. Би та нарын хоорондох зөрчилдөөнүүдийг анхаардаггүй юм биш; зүгээр л Би та нарын нэг биш, тиймээс та нарын дунд оршдог асуудлуудад оролцдоггүй. Би Өөрөө бүтээгдсэн зүйл биш бөгөөд энэ дэлхийнх биш тул хүмүүсийн үймсэн амьдрал болон тэдний хоорондох замбараагүй, зохисгүй харилцаануудыг үзэн яддаг. Би ялангуяа шуугин хашхиралдсан бөөн хүнийг үзэн яддаг. Гэхдээ Би бүтээгдсэн зүйл нэг бүрийн зүрх сэтгэл дэх хольцыг гүн гүнзгий мэддэг бөгөөд та нарыг бүтээхээсээ өмнө Би хүний зүрх сэтгэлийн гүнд оршдог шударга бус байдлыг аль хэдийн мэдэж байсан, мөн хүний зүрх сэтгэл дэх бүх шударга бус, зальжин байдлыг мэдэж байсан. Тиймээс хүмүүсийг шударга бус зүйл хийх үед ямар ч ул мөр байхгүй байсан ч гэсэн, зүрх сэтгэлдээ өвөрлөсөн шударга бус байдал чинь Миний бүтээсэн бүх зүйлийн баялаг байдлаас даван гардаг гэдгийг Би мөн л мэднэ. Та нар дор бүрнээ үй олон хүний оройд хүртэл өргөгдсөн; олон түмний өвөг дээдэс байхаар өргөгдсөн. Та нар туйлын зэрлэг балмад ба бүх өтний дунд улангасан авирлаж, амар тайван орогнох газар эрж хайн, өөрсдөөсөө жаахан өтнүүдийг залгихаар оролддог. Зүрх сэтгэл чинь хорлонтой, зэвүүн байдаг бөгөөд далайн ёроолд живсэн сүнснүүдийг ч даван гарсан. Та нар өтөг бууцны ёроолд оршин сууж, дээрээс доорх хүртэл өтнүүдийг үймүүлэн амар тайванг нь алдагдуулж, өөр хоорондоо хэсэг зуур тэмцэлдээд, дараа нь тайвширдаг. Та нар өөрсдийн байрыг мэддэггүй мөртөө өтөг бууцан дотор бие биетэйгээ тэмцэлдсээр байдаг. Тийм тэмцлээс та нар юу олж авч чадах юм бэ? Хэрвээ та нар үнэхээр Намайг хүндэлдэг зүрх сэтгэлтэй байсан бол Миний ар хударгаар бие биетэйгээ тэмцэлдэж яаж чадах юм бэ? Байр суурь чинь хэчнээн өндөр байх нь хамаагүй, чи бол өтөг баасан доторх өмхий үнэртэй өчүүхэн өт хэвээр бус уу? Чи далавч ургуулан, тэнгэрийн тагтаа болж чадах уу? Өмхий үнэртэй, өчүүхэн жаахан өтнүүд та нар Ехова Миний тахилын ширээнээс тахил хулгайлдаг; ингэснээрээ чи сүйрч, бүтэлгүйтсэн нэр хүндээ аварч, Израилийн сонгогдсон ард болж чадна гэж үү? Ичгүүргүй өөдгүй амьтад! Тахилын ширээн дээрх тэр тахилуудыг хүмүүс Намайг хүндэлдэг сайхан сэтгэлийнхээ илэрхийлэл болгон Надад өргөсөн юм. Тэдгээр нь Миний хяналт, Миний хэрэглээнд зориулагддаг тул чи хүмүүсийн Надад өгсөн бяцхан хүүрзгэнийг

Надаас дээрэмдэж яаж болох юм бэ? Чи Иудас болохоос айдаггүй гэж үү? Газар нутаг чинь цусан талбай болохоос айхгүй байна уу? Ичгүүргүй амьтан! Хүмүүсийн өргөн барьсан хүүрзгэнүүд өт чиний ходоодыг тэжээхийн төлөө байдаг гэж чи бодож байна уу? Чамд Миний өгсөн зүйл бол чамд өгөхдөө үнэн сэтгэлээсээ, дуртайяа өгдөг зүйл юм; Миний чамд өгөөгүй зүйл Миний мэдэлд байх ёстой. Чи зүгээр л Миний тахилуудыг дурааpаа хулгайлж болохгүй. Ажиллаж буй Нэгэн бол бүтээлийн Эзэн—Ехова Би бөгөөд хүмүүс Надаас болж тахил өргөдөг. Энэ нь ийш тийш гүйсний чинь нөхөн төлбөр гэж чи бодож байна уу? Үнэхээр ичгүүргүй юм! Чи хэний төлөө ийш тийш гүйдэг юм бэ? Өөрийнхөө төлөө биш гэж үү? Чи яагаад Миний тахилуудыг хулгайлдаг юм бэ? Чи яагаад Миний түрийвчнээс мөнгө хулгайлдаг юм бэ? Чи Искариотын Иудасын хүү биш гэж үү? Ехова Надад өгсөн тахилуудыг тахилчид эдлэх учиртай. Чи тахилч мөн үү? Чи Миний тахилуудыг маадайн идэж зүрхэлдэг ба бүр тэдгээрийг ширээн дээр тавьдаг; чи ямар ч үнэ цэнгүй! Үнэ цэнгүй өөдгүй амьтан! Ехова Миний гал чамайг үнс нурам болгон шатаана!

МАХАН БИЕТЭЙ ХЭН Ч УУР ХИЛЭНГИЙН ӨДРӨӨС ЗУГТАЖ ЧАДАХГҮЙ

Өнөөдөр Би та нарын оршин тогтнолын төлөө, мөн Өөрийнхөө ажлыг төвөггүй явуулахын төлөө, бүхий л орчлон ертөнц даяарх Өөрийн нээлтийн ажлыг илүү зохистой, төгс байдлаар явуулахын төлөө та нарт сануулга өгч, бүх улс, үндэстний хүмүүст Өөрийн үг, эрх мэдэл, сүр жавхлан, шүүлтийг илчилдэг. Та нарын дунд Миний хийдэг ажил бол бүхий л орчлон ертөнц даяар хийх Миний ажлын эхлэл билээ. Одоо аль хэдийн эцсийн өдрүүдийн цаг үе болсон хэдий ч “эцсийн өдрүүд” гэдэг нь эрин үеийн л нэр гэдгийг мэдэж ав; яг л Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийн адилаар энэ нь сүүлчийн хэдхэн жил, сарыг бус, нэг эрин үеийг хэлдэг бөгөөд бүхий л эрин үеийг илтгэдэг. Гэсэн ч эцсийн өдрүүд нь Нигүүлслийн эрин үе болон Хуулийн эрин үеэс нэлээд ялгаатай. Эцсийн өдрүүдийн ажил Израильд биш, харин Харь үндэстнүүдийн дунд явагддаг; энэ нь Израилийн гаднах бүх үндэстэн, овгийн хүмүүсийг Миний сэнтийн өмнө байлдан дагуулах явдал юм, ингэснээр орчлон ертөнц даяарх Миний алдар суу бүхий л сансар, огторгуйг дүүргэж чадна. Ингэснээр Би илүү агуу алдрыг олж авч, ингэснээр газар дээрх бүх бүтээл Миний алдрыг үндэстэн бүрд, үеийн үед үүрд дамжуулан, тэнгэр газар дахь бүх бүтээл газар дэлхий дээр олж авсан бүх алдрыг минь харж чадна. Эцсийн өдрүүдэд хийгддэг ажил бол байлдан дагуулалтын ажил юм. Энэ нь газар дээрх бүх хүний амьдралын удирдамж биш, харин газар дээрх хүн төрөлхтний барагдашгүй, олон мянган жилийн урт удаан зовлонт амьдралын төгсгөл билээ. Үүний үр дүнд, эцсийн өдрүүдийн ажил нь Израиль дахь хэдэн мянган жилийн

ажилтай адил байж чадахгүй, Бурханыг хоёр дахь удаа бие махбодтой болох хүртэл хоёр мянган жил үргэлжилсэн Иудей дахь хэдхэн жилийн ажилтай ч адил байж чадахгүй. Эцсийн өдрүүдийн хүмүүс махбодоор дахин илэрсэн Золин Аврагчтай л учирч, Бурханы хувийн үг, ажлыг хүлээн авдаг. Эцсийн өдрүүд дуусах хүртэл хоёр мянган жил болохгүй; энэ нь Есүс Иудейд Нигүүлслийн эрин үеийн ажлыг явуулсан үеийнх шиг богинохон байх болно. Учир нь эцсийн өдрүүд бол бүхий л эрин үеийн төгсгөл юм. Эдгээр нь Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний биелэлт, төгсгөл бөгөөд хүн төрөлхтний зовлонт амьдралын аяныг дуусгадаг. Энэ нь бүх хүн төрөлхтнийг шинэ эрин үед аваачдаггүй, хүн төрөлхтний амьдралыг ч үргэлжлүүлдэггүй; тэгэх нь Миний удирдлагын төлөвлөгөөнд, эсвэл хүний оршин тогтнолд ямар ч ач холбогдол агуулахгүй. Хүн төрөлхтөн энэ маягаараа үргэлжлүүлсээр байвал эрт орой хэзээ нэгэн цагт диаволд бүхлээрээ залгиулж, Надад харьяалагддаг тэр сүнснүүд эцэстээ түүний гарт сүйрэх байсан. Миний ажил зургаан мянган жил л үргэлжилдэг бөгөөд бүх хүн төрөлхтнийг хянах муу ёрын нэгний хяналт ч бас зургаан мянган жилээс хэтрэхгүй гэж Би амласан. Ингээд одоо цаг нь боллоо. Би үргэлжлүүлэх ч үгүй, цаашид хойшлуулах ч үгүй: Эцсийн өдрүүдэд Би Сатаныг ялна, Би Өөрийн бүх алдрыг эргүүлэн авч, газар дээр Надад харьяалагддаг бүх сүнсийг буцаан авна, ингэснээр зовлонд нэрвэгдсэн эдгээр сүнс зовлонгийн далайгаас зугтаж, тийнхүү газар дээрх Миний ажил бүхэлдээ дуусна. Энэ өдрөөс хойш Би дахин хэзээ ч газар дээр махбод болохгүй, Миний бүхнийг хянагч Сүнс дахин хэзээ ч газар дээр ажиллахгүй. Газар дээр Би нэг л зүйлийг хийх болно: Би газар дээрх итгэмжит хот минь болох ариун хүн төрөлхтнийг дахин бүтээнэ. Гэхдээ Би бүхий л дэлхий ертөнцийг устгахгүй, бүх хүн төрөлхтнийг ч сөнөөхгүй гэдгийг мэдэж ав. Би үлдсэн тэр гуравны нэгийг нь буюу Намайг хайрладаг, Надаар бүрэн байлдан дагуулагдсан гуравны нэгийг нь авч үлдээд, энэ гуравны нэгийг хуулийн доорх израильчуудын адилаар газар дээр үржүүлж, өсгөн олшруулж, тэднийг элбэг дэлбэг хонь мал, газар дэлхийн бүх эд баялгаар тэтгэнэ. Энэ хүн төрөлхтөн Надтай хамт үүрд үлдэх боловч өнөөдрийн хөөрхийлөлтэй бузар хүн төрөлхтөн биш, харин Миний олж авсан бүх хүнээс бүрдсэн хүн төрөлхтөн байх болно. Ийм хүн төрөлхтнийг Сатан сүйтгэж, үймүүлж, бүслэн авахгүй ба энэ нь Сатаныг ялснаас минь хойш газар дээр оршин тогтнох цорын ганц хүн төрөлхтөн байх болно. Энэ нь өнөөдөр Миний байлдан дагуулсан, Миний амлалтыг хүртсэн хүн төрөлхтөн юм. Иймээс, эцсийн өдрүүдэд байлдан дагуулагдсан хүн төрөлхтөн нь бас өршөөгдөн уучлагдаж, Миний мөнхийн ерөөлийг хүртэх хүн төрөлхтөн юм. Энэ нь Сатаныг ялан дийлсний минь цорын ганц нотолгоо, Сатантай хийсэн тулааны минь цорын ганц олз омог байх болно. Дайны эдгээр олз омгийг Би Сатаны эзэмшлээс аварсан бөгөөд Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний цорын ганц биелэлт, үр жимс юм. Тэд үндэстэн, шашны урсгал бүрээс болон орчлон ертөнц даяарх газар нутаг, улс орон бүрээс гаралтай. Тэд өөр өөр яс үндэс, хэл, зан заншил, арьсны өнгөтэй ба

бөмбөрцгийн бүх үндэстэн, урсгал даяар, тэр ч бүү хэл дэлхийн өнцөг булан бүрд тархсан байдаг. Эцэст нь тэд бүрэн төгс хүн төрөлхтөн буюу Сатаны хүчинд авташгүй хүмүүсийн цугларалтыг бүрдүүлэхийн тулд нэгдэх болно. Хүн төрөлхтний дундах, Миний аварч, байлдан дагуулаагүй хүмүүс далайн гүнд чимээ аниргүй живж, бүхнийг залгигч галд минь мөнхөд шатаагдана. Би Египетийн ууган хөвгүүд, ууган төлийг устгаад, хурганы мах идэж, хурганы цус ууж, хаалганыхаа тотгонд хурганы цусаар тэмдэг тавьсан израильчуудыг л үлдээж байсныхаа адилаар хуучин, туйлын бузар энэ хүн төрөлхтнийг устгана. Миний байлдан дагуулсан хүмүүс болон Миний гэр бүлийнхэн ч бас Хурга Миний махыг идэж, Хурга Миний цусыг уудаг, Надаар золин авруулсан, Надад шүтэн мөргөдөг хүмүүс биш гэж үү? Ийм хүмүүсийг Миний алдар үргэлж дагалддаггүй гэж үү? Хурга Миний махгүй хүмүүс аль хэдийн далайн гүнд чимээгүйхэн живээгүй гэж үү? Өнөөдөр та нар Намайг эсэргүүцдэг ба өнөөдөр Миний үг Израилийн хөвгүүд, ач гуч нарт хэлсэн Еховагийн үгтэй яг адилхан. Гэсэн ч та нарын зүрх сэтгэлийн гүн дэх хөшүүн байдал Миний уур хилэнг хуримтлуулж, махан биед чинь илүү их зовлонг, нүгэлд чинь илүү их шүүлтийг, зөв шударга бус байдалд чинь илүү их уур хилэнг авчирч байна. Өнөөдөр та нар Надад ингэж хандаж байхад Миний уур хилэнгийн өдрөөс хэн зугтаж чадах юм бэ? Хэний зөв шударга бус байдал гэсгээлтийн харцнаас минь зайлж чадах юм бэ? Төгс Хүчит Миний гараас хэний нүгэл мултарч чадах юм бэ? Төгс Хүчит Миний шүүлтээс хэний эсэргүүцэл зайлж чадах юм бэ? Ехова Би Харь үндэстний үр удам болох та нартай ийнхүү ярьж, та нарт хэлдэг Миний үг Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийн бүх айлдвараас давдаг, гэхдээ та нар Египетийн бүх хүнээс илүү хатуу юм. Намайг тайвнаар ажлаа хийх зуур та нар Миний уур хилэнг хуримтлуулдаг бус уу? Төгс Хүчит Миний өдрөөс та нар яаж эсэн мэнд зугтаж чадах билээ?

Би та нарын дунд ийм маягаар ажиллаж, үг хэлсэн, Би маш их эрч хүч, хүчин чармайлт зарцуулсан, гэвч Миний ний нуугүй хэлдэг зүйлийг та нар ер нь хэзээ сонсож байсан юм бэ? Та нар Төгс Хүчит Надад хаана мэхийн ёсолж байсан юм бэ? Та нар Надад яагаад ингэж ханддаг юм бэ? Яагаад та нарын хэлдэг, хийдэг бүхэн Миний уурыг хүргэдэг юм бэ? Яагаад та нарын зүрх сэтгэл ийм хатуу юм бэ? Би ер нь та нарыг цохин унагаж байсан уу? Яагаад та нар Намайг уй гашуу, түгшүүртэй болгохоос өөрийг хийдэггүй юм бэ? Та нар Ехова Миний уур хилэн өөрсөд дээр чинь буух өдрийг хүлээгээ юү? Дуулгаваргүй байдлаас чинь болж уураа илгээхийг минь та нар хүлээж байна уу? Миний хийдэг бүхэн та нарын төлөө байдаг бус уу? Гэтэл та нар Ехова Надад үргэлж ингэж хандаж ирсэн: тахилыг минь хулгайлж, бэлтрэг, зулзаганууды тэжээхийн тулд Миний тахилын ширээн дээрх өргөлийг чонын үүрэн дэх гэртээ аваачиж; хүмүүс бие биетэйгээ тэмцэлдэж, ууртай харц, сэлэм жадтайгаар бие биетэйгээ нүүр тулж, баас шиг бохир заваан болгох гэж Төгс Хүчит Миний үгийг жорлон руу чулууддаг. Ёс жудаг чинь хаана байна? Хүн чанар чинь зэрлэг догшин болжээ! Зүрх сэтгэл чинь аль эрт чулуу болон хувирчээ.

Миний уур хилэнгийн өдөр ирэх үе бол Төгс Хүчит Миний эсрэг өнөөдөр үйлддэг муу муухайг чинь шүүх үе байх болно гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Ийм маягаар Намайг хууран, Миний үгийг шавар шавхайд хаяж, сонсохгүй байснаар—Миний ар хударгаар ингэж авирласнаар Миний хилэнт харцнаас зайлсхийж чадна гэж та нар бодож байна уу? Миний тахилыг хулгайлж, Миний эд хөрөнгөд санаархахдаа та нар Ехова Миний нүдэнд аль хэдийн харагдсан гэдгээ мэдэхгүй байна уу? Миний тахилыг хулгайлах үедээ тахил өргөдөг тахилын ширээний өмнө хулгайлсан гэдгээ та нар мэдэхгүй байна уу? Намайг ийм маягаар хуурч чадахуйц ухаалаг гэдэгтээ та нар яаж итгэж чадав аа? Миний уур хилэн та нарын жигшүүрт нүглийг зүгээр орхиж яаж чадах юм бэ? Миний догшин уур омог муу ёрын үйлийг чинь зүгээр өнгөрөөж яаж чадах юм бэ? Өнөөдөр үйлддэг муу муухай чинь та нарт гарах гарц нээж өгөхгүй, харин маргаашийн гэсгээлтийг чинь хуримтлуулдаг; энэ нь Төгс Хүчит Миний гэсгээлтийг та нар луу өдөөдөг. Та нарын муу үг, муу үйл Миний гэсгээлтээс зайлж яаж чадах юм бэ? Залбирал чинь яаж Миний чихэнд хүрч чадах юм бэ? Та нарын зөв шударга бус байдалд Би гарах гарц нээж өгч яаж чадах юм бэ? Намайг эсэргүүцдэг муу үйлийг чинь Би яаж зүгээр өнгөрөөж чадах юм бэ? Могойнх шиг хорт хэлийг чинь Би яаж таслахгүй байж чадах юм бэ? Зөв шударга байдлынхаа төлөө та нар Намайг дууддаггүй, харин зөв шударга бус байдлынхаа үр дүнд уур хилэнг минь хуримтлуулдаг. Би та нарыг яаж уучилж чадах юм бэ? Төгс Хүчит Миний нүдэнд үг, үйлдэл чинь бузар заваан байдаг. Төгс Хүчит Миний нүд та нарын зөв шударга бус байдлыг өршөөлгүй гэсгээлт гэж хардаг. Миний зөвт гэсгээлт, шүүлт та нарыг орхиж яахан чадах билээ? Та нар Надад ингэж хандан, Намайг уйтгар гунигтай, уур хилэнтэй болгодог учраас Ехова Би та нарыг гараасаа бултуулж, та нарыг гэсгээж, хараах өдрөө орхиж яахан чадах билээ? Бүх муу үг, яриа чинь аль хэдийн Миний чихэнд хүрснийг та нар мэдэхгүй гэж үү? Та нарын зөв шударга бус байдал Миний зөвт байдлын ариун өмсгөлийг аль хэдийн буртагласныг мэдэхгүй гэж үү? Дуулгаваргүй байдал чинь аль эрт дүрсхийх уурыг минь хүргэсэн гэдгийг мэдэхгүй гэж үү? Аль хэдийнээс та нар Намайг хилэгнүүлж, тэвчээрийг минь барснаа мэдэхгүй гэж үү? Та нар Миний махбодыг аль хэдийн сүйдэлж, навсайлгаж орхисноо мэдэхгүй гэж үү? Би өнөөг хүртэл тэвчсэн, тийм болохоор Би уураа гаргаж, цаашид та нарт хүлээцтэй хандахгүй. Та нарын муу үйл аль хэдийн нүдэнд минь өртөж, Миний хашхираан аль хэдийн Эцэгийн минь чихэнд хүрсэн гэдгийг та нар мэдэхгүй байна уу? Надад ингэж хандахыг чинь Тэр яаж зөвшөөрч чадах юм бэ? Та нарт Миний хийдэг аливаа ажил та нарын төлөө байдаг бус уу? Гэтэл та нараас хэн чинь Ехова Миний ажлыг илүү их хайрлах болсон бэ? Би сул дорой учраас, мөн зовлон зүдүүр туулсан учраас Эцэгийнхээ хүсэлд үнэнч бус байдаг гэж үү? Та нар Миний зүрх сэтгэлийг ойлгохгүй байна уу? Би та нартай Еховагийн адилаар ярьж байна; Би та нарын төлөө өчнөөн ихийг зориулаагүй гэж үү? Эцэгийнхээ ажлын төлөө энэ бүх зовлонг туулахад Би бэлэн байгаа хэдий ч Өөрийнхөө зовлонгоос үүдэн өөрсдөд чинь авчрах гэсгээлтээс та нар яаж

чөлөөлөгдөж чадах юм бэ? Та нар Надаас маш ихийг эдлээгүй гэж үү? Өнөөдөр, Миний Эцэг Намайг та нарт хайрласан; та нар Миний элбэг дэлбэг үгээс хавьгүй ихийг эдэлсэн гэдгээ мэдэхгүй байна гэж үү? Миний амийг та нарын амиар болон эдэлдэг зүйлсээр чинь сольсон гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Миний Эцэг Сатантай тулалдахын тулд Миний амийг ашиглаж, бас та нарт Миний амийг хайрлаж, та нарт зуу дахин ихийг хүртээж, маш олон уруу таталтаас зайлсхийх боломж олгосныг мэдэхгүй гэж үү? Миний ажлаар л дамжуулан олон уруу таталт, олон ширүүн гэсгээлтээс чөлөөлөгдсөн гэдгээ та нар мэдэхгүй гэж үү? Надаас болж л Миний Эцэг та нарыг өнөөг хүртэл баясуулан цэнгүүлдэг гэдгийг мэдэхгүй гэж үү? Зүрх сэтгэлд чинь эвэр ургачихсан мэт та нар өнөөдөр яаж ийм хатуу, нугаршгүй хэвээр үлдэж чадна вэ? Намайг газар дэлхийгээс явсны дараа болох уур хилэнгийн өдрөөс өнөөдөр үйлдэж буй муу муухай чинь яаж мултарч чадах юм бэ? Ийм хатуу, нугаршгүй хүмүүсийг Би яаж Еховагийн уур хилэнгээс зугтаалгаж чадах юм бэ?

Өнгөрснийг бодоод үз: Та нар луу чиглэсэн харц минь хэзээ ууртай, дуу хоолой минь хэзээ ширүүн байсан юм бэ? Би хэзээ өчүүхэн зүйлээс болж та нартай маргалдаж байсан бэ? Би хэзээ та нарыг үндэслэлгүйгээр зэмлэж байсан бэ? Би хэзээ та нарыг нүүрэн дээр чинь зэмлэсэн бэ? Би ажлынхаа төлөө л, та нарыг уруу таталт болгоноос хамгаалахын тулд л Эцэгийгээ дууддаг бус уу? Яагаад та нар Надад ингэж ханддаг юм бэ? Та нарын махан биеийг цохиж унагахын тулд Би эрх мэдлээ ер нь ашигласан гэж үү? Та нар яагаад Миний ачийг ингэж хариулдаг юм бэ? Надад яаж хандах гэж байгаа нь мэдэгдэхгүй байсныхаа дараа та нар халуун ч биш, хүйтэн ч биш байдаг, тэгснээ Намайг аргалахаар оролдож, Надаас юм нуудаг ба ам чинь зөв шударга бус шүлсээр дүүрэн байдаг. Та нарын хэл Миний Сүнсийг хуурч чадна гэж бодож байна уу? Хэл чинь Миний уур хилэнгээс зугтаж чадна гэж бодоо юу? Хэл чинь Ехова Миний үйл хэргийг хүссэнээрээ шүүмжилж болно гэж бодоо юу? Би хүнээр шүүгддэг Бурхан гэж үү? Өчүүхэн өт хорхой Намайг ингэж доромжлохыг Би зөвшөөрч чадна гэж үү? Ийм дуулгаваргүй хөвгүүдийг Би мөнхийн ерөөлдөө байлгаж яаж чадах юм бэ? Та нарын үг, үйлдэл аль хэдийн ил болж, та нарыг ялласан. Би тэнгэрийг дэлгэж, бүх зүйлийг бүтээхдээ ямар ч бүтээлд дурааараа оролцохыг зөвшөөрөөгүй, Миний ажлыг, Миний удирдлагыг хүссэнээрээ тасалдуулахыг ямар ч зүйлд бүр ч зөвшөөрөөгүй. Би хэнийг ч, юуг ч тэвчээгүй; Надад хүнлэг бус, харгис ханддаг тэднийг Би яаж өршөөж чадах юм бэ? Миний үгийн эсрэг тэрсэлдэг хүмүүсийг Би яаж уучилж чадах юм бэ? Надад дуулгаваргүй байдаг хүмүүсийг Би яаж өршөөж чадах юм бэ? Хүний хувь заяа Төгс Хүчит Миний гарт байдаг бус уу? Би чиний зөв шударга бус, дуулгаваргүй байдлыг яаж цэвэр ариун гэж үзэж чадах юм бэ? Нүгэл чинь Миний ариун байдлыг бузарлаж яаж чадах юм бэ? Би зөв шударга бус хүмүүсийн хольцоор бохирдохгүй, зөв шударга бус хүмүүсийн өргөлийг ч таалахгүй. Хэрвээ чи Ехова Надад үнэнч байсан бол Миний тахилын ширээн дээрх тахилуудыг өөртөө авч чадах байсан уу? Миний ариун нэрийг доромжлохын тулд хорт хэлээ ашиглаж чадах байсан уу? Ийм

маягаар чи Миний үгийн эсрэг тэрсэлж чадах байсан уу? Миний алдар суу, ариун нэрийг чи муу ёрын нэгэн болох Сатанд үйлчлэх хэрэгсэл мэтээр үзэж чадах байсан уу? Ариун хүмүүсээр эдлүүлэхийн тулд Миний амь өгөгдсөн. Амиар минь хүссэнээрээ тоглож, өөр хоорондох зөрчилдөөнийхөө хэрэгсэл болгон ашиглахыг чинь Би яаж зөвшөөрч чадах юм бэ? Та нар яаж ийм харгис цэвдэг байж, сайны зам болон Надад хандах хандлагадаа яаж ийм дутуу дулимаг байж чадна вэ? Эдгээр амийн үгэнд Би ёрын муу үйлийг чинь аль хэдийн бичсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Египетийг гэсгээх үеийн минь уур хилэнгийн өдрөөс та нар яаж зугтаж чадах юм бэ? Та нар ийм маягаар ахин дахин Намайг эсэргүүцэж, Надад тэрслэхийг Би яаж зөвшөөрч чадах юм бэ? Би та нарт илэн далангүй хэлье, цаг нь ирэхэд та нарын гэсгээлт Египетийнхээс илүү тэсвэрлэшгүй байх болно! Та нар Миний уур хилэнгийн өдрөөс яаж зугтаж чадах юм бэ? Би үнэнээр та нарт хэлье: Миний тэвчээр ёрын муу үйлийн чинь төлөө бэлтгэгдсэн ба тэр өдрийн гэсгээлтийн чинь төлөө оршдог. Намайг тэсгэл алдах үед уур хилэнт шүүлт амсах хүмүүс нь та нар бус уу? Бүх зүйл Төгс Хүчит Миний гарт байдаг бус уу? Тэнгэрийн дор Надад ингэж дуулгаваргүй хандахыг чинь Би яаж зөвшөөрч чадах билээ? Ирнэ гэгдэж байсан атлаа хэзээ ч ирээгүй Мессиатай уулзсан учраас та нарын амьдрал маш хэцүү байх болно. Та нар Түүний дайснууд биш үү? Есүс та нарын анд нөхөр байсан ч та нар Мессиагийн дайсан юм. Та нар Есүстэй анд нөхөр ч гэсэн, ёрын муу үйл чинь жигшүүрт хүмүүсийн савыг дүүргэсэн гэдгийг мэдэхгүй гэж үү? Та нар Еховатай маш ойр дотно байдаг ч ёрын муу үг чинь Еховагийн чихэнд хүрч, уур хилэнг нь бадраасан гэдгийг мэдэхгүй гэж үү? Тэр яаж чамтай ойр дотно байж, муу үйлээр дүүрэн савыг чинь шатаахгүй байж чадах юм бэ? Тэр яаж чиний дайсан биш байх юм бэ?

АВРАГЧ АЛЬ ХЭДИЙН “ЦАГААН ҮҮЛЭН” ДЭЭР ЭРГЭН ИРСЭН

Аврагчийн ирэхийг нүдээр үзэж чадах юм сан хэмээн хүн хэдэн мянган жилийн туршид эгээрэн хүссэн. Мянга мянган жилийн турш Өөрийг нь санан бэтгэрч, хүсэн мөрөөссөн хүмүүсийн дунд Аврагч Есүс цагаан үүл хөлөглөн, Өөрийн биеэр бууж ирэхийг хүн харахыг хүссэн. Хүн бас Аврагч эргэн ирж, бидэнтэй эргэн нэгдээсэй гэж хүсэн хүлээж байсан. Өөрөөр хэлбэл, хэдэн мянган жилийн туршид хүмүүсээс алс байсан Аврагч Есүсийг буцаад ирээсэй, иудейчүүдийн дунд хийсэн золин аврах ажлаа дахин нэг удаа хэрэгжүүлж, хүнд энэрэнгүй, хайр энэрэлтэй хандаасай, хүний нүглийг уучилж, хүний нүглийг үүрч, тэр ч бүү хэл хүний бүх гэм бурууг үүрч, хүнийг нүглээс гэтэлгээсэй хэмээн хүн хүсэмжилдэг. Тэд Аврагч Есүсийг өмнөхтэйгөө адил хайр татам, нөхөрсөг, эрхэм бөгөөд хэзээ ч хүнд хилэгнэдэггүй, хэзээ ч хүнийг зэмлэдэггүй Аврагч байгаасай, энэ Аврагч нь хүний бүх нүглийг

уучилж, хариуцлагыг нь үүрч, бүр хүний төлөө өмнөх шигээ загалмай дээр нас эцэслээсэй гэж хүсэн хүлээдэг. Есүсийг явснаас хойш Түүнийг дагаж байсан шавь нар болоод Түүний нэрийн ачаар аврагдсан ариун хүмүүс бүгд цөхрөнгөө баран Түүнийг санан бэтгэрч, хүлээсээр ирсэн юм. Нигүүлслийн эрин үед Есүс Христийн нигүүлслээр аврагдсан бүх хүн Аврагч Есүс цагаан үүлэн дээр буун ирж, бүх хүний дунд гарч ирэх эцсийн өдрүүд дэх тэр нэгэн баярт өдрийг хүсэмжилсээр байна. Мэдээж энэ бол мөн өнөөдөр Аврагч Есүсийн нэрийг хүлээн авч байгаа бүх хүний хамтын хүсэл юм. Есүс Христ газар дэлхий дээр байхдаа хэлсэн “Би яг л явсан шигээ ирнэ” гэх үгээ биелүүлэхээр гэнэт ирэхийг нь орчлон ертөнц даяарх Аврагч Есүсийн авралыг мэддэг бүх хүн цөхрөнгөө баран хүсэн хүлээсээр ирлээ. Цовдлуулж, дахин амилсныхаа дараа Есүс цагаан үүлэн дээр тэнгэр өөд буцан явж, Хамгийн Дээд Нэгний баруун талд Өөрийн байрыг эзэлсэн гэж хүн боддог. Үүний адилаар, Есүс Өөрийг нь хэдэн мянган жилийн турш цөхрөнгөө баран хүсэн хүлээсэн хүмүүсийн дунд дахин, цагаан үүлэн дээр (энэ үүл нь Есүс тэнгэр лүү буцахдаа хөлөглөсөн үүлийг хэлж байна) бууж ирэх ба иудейчүүдийн дүр төрх болон хувцастай байх юм. Тэрээр хүний өмнө гарч ирснийхээ дараа тэдэнд хоол хүнс хайрлаж, тэдний төлөө амийн ус ундруулаад, хүмүүсийн дунд хайр, нигүүлслээр дүүрэн, амьд, бодитоор амьдрах болно. Энэ бүх үзэл нь хүмүүсийн боддог зүйл юм. Гэвч Аврагч Есүс ингээгүй; Тэр хүний төсөөлснөөс эсрэг зүйл хийсэн. Эргэн ирэхийг нь хүсэн хүлээж байсан хүмүүсийн дунд Тэр ирээгүй, бас цагаан үүл хөлөглөж бүх хүнд харагдаагүй. Тэр аль хэдийн ирчихсэн боловч хүн мэддэггүй бөгөөд мэдлэггүй хэвээр үлддэг. Хүн Түүнийг зүгээр л зорилгогүй хүлээж байгаа бөгөөд Түүнийг аль хэдийн “цагаан үүлэн” дээр (тэр үүл бол Түүний Сүнс, Түүний үг, Түүний бүхий л зан чанар болоод Тэр юу болох юм) бууж ирчхээд, одоо эцсийн өдрүүдэд бий болгох бүлэг ялагчдынхаа дунд байгаа гэдгийг мэддэггүй. Хүн үүнийг мэдэхгүй: Ариун Аврагч Есүс хүнийг гэсэн хайр, энхрийллээр дүүрэн боловч бузар буртаг, ариун бус сүнснүүдийн амьдран суудаг “сүмүүдэд” ажиллаж яаж чадах юм бэ? Түүний ирэхийг хүн хүлээсээр байгаа боловч зөв шударга бусын махыг идэж, зөв шударга бусын цусыг ууж, зөв шударга бусын хувцас өмсдөг, Түүнд итгэдэг атлаа Түүнийг мэддэггүй, Түүнийг үргэлж сүрдүүлж юм авдаг хүмүүст Тэр яаж харагдаж чадах юм бэ? Хүн Аврагч Есүсийг хайраар дүүрч, энэрэл ундарсан бөгөөд золин авралаар дүүрэн нүглийн тахил юм гэдгийг л хүн мэддэг. Харин Тэр бас зөвт байдал, сүр жавхлан, уур хилэн, шүүлтээр бялхаж, эрх мэдлийг эзэмшсэн, эрхэм чанараар дүүрэн Бурхан Өөрөө мөн гэдгийг хүн огт мэддэггүй. Иймээс хүн хэдийгээр Золин аврагчийн эргэж ирэхийг эгээрэн хүсэн хүлээж, мөрөөсөл болдог бөгөөд “Тэнгэр” хүртэл хүний залбиралд уярсан ч гэсэн, Өөрт нь итгэдэг ч Өөрийг нь мэддэггүй хүмүүст Аврагч Есүс харагддаггүй.

“Ехова” бол Израиль дахь ажлынхаа үед Миний авсан нэр бөгөөд хүнийг өрөвдөж, хүнийг хараж, хүний амьдралыг замчилж чаддаг израильчуудын (Бурханы сонгосон хүмүүс) Бурхан гэсэн утгатай юм. Энэ нь агуу хүч чадлыг

эзэмшсэн, мэргэн ухаанаар дүүрэн Бурхан гэсэн утгатай. “Есүс” бол Иммануел бөгөөд хайраар дүүрэн, энэрлээр дүүрэн, хүнийг золин авардаг нүглийн тахил гэсэн утгатай юм. Тэр Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийсэн, Нигүүлслийн эрин үеийг төлөөлдөг ба удирдлагын төлөвлөгөөний нэг хэсгийг л төлөөлж чадна. Өөрөөр хэлбэл, Ехова л Израилийн сонгогдсон хүмүүсийн Бурхан, Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан, Иаковын Бурхан, Мосегийн Бурхан, Израилийн бүх ард түмний Бурхан юм. Иймээс өнөөгийн эрин үед иудей хүмүүсээс бусад бүх израильчууд Еховаг шүтэн мөргөдөг. Тэд тахилын ширээн дээр Түүнд тахил өргөж, сүмд тахилчийн хувцас өмсөн Түүнд үйлчилдэг. Тэдний найддаг зүйл нь Еховагийн дахин илрэлт юм. Зөвхөн Есүс л хүн төрөлхтний Золин аврагч билээ. Тэр бол хүн төрөлхтнийг нүглээс золин аварсан нүглийн тахил юм. Өөрөөр хэлбэл, Есүсийн нэр Нигүүлслийн эрин үеэс гаралтай ба Нигүүлслийн эрин үеийн золин авралын ажлаас болж бий болсон юм. Нигүүлслийн эрин үеийн хүмүүст дахин төрж, аврагдах боломж олгохын тулд Есүс гэх нэр бий болсон бөгөөд энэ нь бүхий л хүн төрөлхтний золин авралын төлөөх онцгой нэр юм. Иймээс Есүс хэмээх нэр золин авралын ажлыг төлөөлж, Нигүүлслийн эрин үеийг илэрхийлдэг. Ехова хэмээх нэр нь хуулийн дагуу амьдарч байсан Израилийн ард түмний төлөөх онцгой нэр юм. Эрин үе, ажлын үе шат болгон дахь Миний нэр ул үндэсгүй биш, харин бэлгэдлийн ач холбогдлыг агуулдаг: Нэр болгон нэг эрин үеийг төлөөлдөг. “Ехова” нь Хуулийн эрин үеийг төлөөлдөг бөгөөд Израилийн ард түмний шүтэн мөргөдөг Бурханаа дууддаг хүндэтгэсэн нэр юм. “Есүс” нь Нигүүлслийн эрин үеийг төлөөлдөг ба Нигүүлслийн эрин үед золин аврагдсан бүх хүний Бурханы нэр билээ. Хэрэв хүн эцсийн өдрүүдэд бас л Аврагч Есүсийг ирээсэй гэж хүсэн хүлээж, Түүнийг мөн л Иудейд байсан төрхөөрөө ирнэ гэж бодвол бүхэл бүтэн зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө Золин авралын эрин үед зогсож, цаашид ахин дэвших боломжгүй болох байлаа. Түүнчлэн эцсийн өдрүүд хэзээ ч ирэхгүй, эрин үе хэзээ ч төгсөхгүй байх байв. Аврагч Есүс зөвхөн хүн төрөлхтний золин аврал болон авралын төлөө байдаг учраас тэр юм. Нигүүлслийн эрин үе дэх бүх нүгэлтний төлөө Би Есүс хэмээх нэрийг авсан бөгөөд бүхий л хүн төрөлхтнийг төгсгөлд аваачих нэр минь энэ биш. Ехова, Есүс, Мессиа нь бүгд Миний Сүнсийг төлөөлдөг боловч, эдгээр нэр Миний удирдлагын төлөвлөгөөний өөр өөр эрин үеийг л илэрхийлдэг болохоос Намайг бүрэн дүүрэн төлөөлдөггүй. Газар дэлхий дээрх хүмүүсийн Намайг дууддаг нэрс нь Миний бүх зан чанарыг болон Би юу болохыг тодорхойлж чадахгүй. Тэдгээр нь зүгээр л, өөр өөр эрин үед Намайг дууддаг өөр өөр нэр юм. Иймээс сүүлийн эрин үе буюу эцсийн өдрүүдийн эрин үе ирэхэд Миний нэр дахин өөрчлөгдөнө. Намайг Мессиа гэх нь байтугай Ехова, Есүс ч гэж нэрлэхгүй, харин хүчирхэг Төгс Хүчит Бурхан Өөрөө гэж нэрлэх ба энэ нэрийн дор Би бүхий л эрин үеийг төгсгөх болно. Намайг нэг үе Ехова гэдэг байсан. Түүнчлэн Мессиа гэж дууддаг байсан ба хүмүүс хайрлаж хүндэлсэндээ Аврагч Есүс гэж нэг үе нэрлэсэн. Гэвч өнөөдөр Би өнгөрсөн үед хүмүүсийн мэддэг байсан Ехова юм уу

Есүс биш, харин эцсийн өдрүүдэд эргэж ирсэн Бурхан, энэ эрин үеийн төгсгөлийг авчрах Бурхан билээ. Би бол газрын мухраас өндийн босож, Өөрийн бүх зан чанараар бялхдаг, эрх мэдэл, нэр төр, алдар суугаар дүүрэн Бурхан Өөрөө билээ. Хүмүүс Надтай хэзээ ч харьцаж байгаагүй, Намайг хэзээ ч мэдэж байгаагүй бөгөөд Миний зан чанарыг хэзээд мэдэхгүй байсаар ирсэн. Дэлхийг бүтээснээс эхлээд өнөөдрийг хүртэл нэг ч хүн Намайг хараагүй. Энэ бол эцсийн өдрүүдэд хүнд харагддаг атлаа хүмүүсийн дунд нуугдаж байдаг Бурхан билээ. Тэрээр хүмүүсийн дунд үнэн, бодитоор амьдран суудаг ба төөнөх нар, дүрэлзэх гал адил хүч чадлаар дүүрч, эрх мэдлээр бялхан байдаг. Миний үгээр шүүгдэхгүй ганц ч хүн, нэг ч зүйл байхгүй, дүрэлзэх галаар ариусгагдахгүй ганц ч хүн, нэг ч зүйл байхгүй. Яваандаа бүх улс орон Миний үгээс болоод ерөөгдөнө, мөн Миний үгээс болж бут ниргүүлнэ. Энэ маягаар, эцсийн өдрүүдэд бүх хүн Намайг эргэж ирсэн Аврагч гэдгийг, бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулдаг Төгс Хүчит Бурхан гэдгийг, бас нэгэнтээ хүний төлөөх нүглийн тахил байсан боловч эцсийн өдрүүдэд мөн бүх зүйлийг шатаах нарны дөл, бүх зүйлийг илчлэх зөвт байдлын Нар болдгийг минь харна. Эцсийн өдрүүдийн Миний ажил энэ юм. Би бол зөвт Бурхан агаад төөнөх нар, дүрэлзэх гал гэдгийг бүх хүнд харуулахын тулд энэ нэрийг авч, энэ зан чанарыг эзэмшсэн юм. Ингэснээр цорын ганц жинхэнэ Бурхан болох Намайг бүх хүн шүтэн мөргөж, тэгснээрээ тэд Миний жинхэнэ царайг харах юм: Би бол зөвхөн израильчуудын Бурхан биш, мөн зөвхөн Золин аврагч биш, харин тэнгэр, газар, тэнгис далай даяарх бүх бүтээлийн Бурхан билээ.

Аврагч эцсийн өдрүүдэд ирэхдээ мөн л Есүс гэгдэн, дахин Иудейд төрж, Иудейд ажлаа хийсэн бол, Би зөвхөн Израилийн ард түмнийг л бүтээж, Израилийн ард түмнийг л золин аварсан ба Харь үндэстнүүдтэй ямар ч хамаагүй гэдгийг энэ нь нотлох байсан. “Би бол тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн Эзэн” хэмээх Миний үгтэй энэ нь зөрчилдөх байсан бус уу? Би Иудейг орхисон бөгөөд Харь үндэстнүүдийн дунд ажлаа хийдэг, учир нь Би бол зөвхөн Израилийн ард түмний Бурхан биш, харин бүх бүтээлийн Бурхан билээ. Би Израилийн ард түмний Бурхан Ехова төдийгүй Харь үндэстнүүдийн дундах Өөрийн сонгосон бүх хүний Бүтээгч тул эцсийн өдрүүдэд Харь үндэстнүүдийн дунд гарч ирдэг. Би Израиль, Египет, Ливаныг төдийгүй Израилийн чанад дахь бүх Харь үндэстнийг бүтээсэн. Ийм учраас Би бол бүх бүтээлийн Эзэн билээ. Би Израилийг ердөө л ажлынхаа эхлэлийн цэг болгон ашиглаж, Иудей болон Галилыг золин аврах ажлынхаа түшиц газар болгон хэрэглэсэн, харин одоо бүхий л эрин үеийг төгсгөхдөө Харь үндэстнүүдийг суурин газраа болгон ашиглана. Би Израильд ажлын хоёр үе шатыг (Хуулийн эрин үе ба Нигүүлслийн эрин үеийн ажлын хоёр үе шат) хийсэн бөгөөд Израилийн чанад дахь газар нутаг даяар бас ажлын хоёр үе шатыг (Нигүүлслийн эрин үе ба Хаанчлалын эрин үе) хэрэгжүүлсээр байна. Харь үндэстнүүдийн дунд Би байлдан дагуулах ажлыг хийж, эрин үеийг ийнхүү төгсгөнө. Хэрвээ хүн, эцсийн өдрүүдэд шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажил хийж эхэлсэн гэдгийг минь

мэдэлгүй, Намайг дандаа Есүс Христ гэж дууддаг бол, мөн Аврагч Есүсийн ирэхийг үргэлж хэнхэглэн хүлээдэг бол тийм хүмүүсийг Би Надад итгэдэггүй хүмүүс гэж хэлнэ. Тэд бол Намайг мэддэггүй хүмүүс бөгөөд Надад итгэх итгэл нь хуурамч юм. Тийм хүмүүс Аврагч Есүсийн тэнгэрээс ирэхийг нүдээр үзэж чадах уу? Тэд Миний ирэхийг биш, харин иудейчүүдийн Хааны ирэхийг л хүлээдэг билээ. Ариун бус, хуучин энэ ертөнцийг бүрэн устгахыг минь тэд хүсэн мөрөөсдөггүй, харин өөрсдөө золин аврагдах гэсэндээ Есүсийн хоёр дахиа ирэхийг хүсэн хүлээдэг. Есүс энэхүү бузартсан, зөв шударга бус газраас бүх хүн төрөлхтнийг дахин нэг удаа золин аврахыг тэд хүлээдэг. Ийм хүмүүс эцсийн өдрүүд дэх Миний ажлыг гүйцэлдүүлэх хүмүүс болж яаж чадах юм бэ? Хүний хүсэл Миний хүслийг биелүүлж, Миний ажлыг хэрэгжүүлэх чадалгүй, учир нь хүн ердөө л Миний урьд нь хийсэн ажлыг биширч, нандигнадаг болохоос Намайг үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан Өөрөө гэдгийг огт мэддэггүй. Хүн Намайг Ехова, бас Есүс гэдгийг л мэддэг болохоос хүн төрөлхтнийг төгсгөлд аваачих эцсийн өдрүүдийн Нэгэн гэдгийг огт мэддэггүй. Хүний хүсэн хүлээдэг, мэддэг зүйл нь бүгд түүний үзлээс улбаатай бөгөөд энэ нь ердөө л тэдний хоёр нүдээрээ харж чадах зүйл байдаг. Тэр нь Миний хийдэг ажилтай нийцдэггүй, харин зөрчилддөг. Хэрвээ Миний ажил хүний санаагаар болдог байсан бол энэ хэзээ дуусах билээ? Хүн төрөлхтөн хэзээ амралтад орох юм бэ? Бас Би яаж долоо дахь өдөр Амралтын өдөрт орж чадах юм бэ? Би хүний санаа зорилгын дагуу бус, Өөрийнхөө төлөвлөгөө, зорилгын дагуу ажилладаг.

САЙН МЭДЭЭ ТҮГЭЭХ АЖИЛ НЬ БАС ХҮНИЙГ АВРАХ АЖИЛ МӨН

Газар дээрх Миний ажлын зорилгыг, өөрөөр хэлбэл, Миний хүрэхийг хүсэж байгаа эцсийн зорилтыг, мөн энэ ажил бүрэн төгс болохоос өмнө Би үүгээр ямар түвшинд хүрэх ёстойг бүх хүн ойлгох хэрэгтэй. Хүмүүс өнөөдрийг хүртэл Надтай цуг алхчхаад Миний ажил чухам ямар учиртайг ойлгодоггүй бол тэд Надтай хамт дэмий алхаж байсан бус уу? Намайг дагадаг бол хүмүүс Миний хүслийг мэддэг байх ёстой. Би газар дээр хэдэн мянган жилийн турш ажиллаж байгаа бөгөөд өнөөдөр ч гэсэн Өөрийн ажлыг энэ маягаар хэрэгжүүлж байна. Миний ажил асар олон төслийг хамардаг хэдий ч зорилго нь нэг хэвээрээ байдаг; жишээлбэл, Би хүнд шүүлт, гэсгээлтээр дүүрэн ханддаг хэдий ч Миний хийдэг зүйл түүнийг аврахын төлөө л байдаг, хүнийг бүрэн төгс болсны дараа Өөрийн сайн мэдээг илүү сайн түгээж, Өөрийн ажлыг бүх Харь үндэстний дунд өргөжүүлэхийн төлөө байдаг. Иймээс өнөөдөр, олон хүн аль эртнээс сэтгэлийн гүн хямралд орчхоод байгаа энэ үед ч Би ажилласаар байдаг, хүнийг шүүж, гэсгээхийн тулд хийх ёстой ажлаа Би үргэлжлүүлдэг. Хүн Миний хэлдэг зүйлээс залхчихсан бөгөөд Миний ажлыг

анхаарах ямар ч хүсэлгүй байдаг нь үнэн ч гэсэн, Би Өөрийн үүргээ хэрэгжүүлсээр байгаа, учир нь Миний ажлын зорилго өөрчлөгдөлгүй үлддэг бөгөөд Миний анхны төлөвлөгөө ч нурахгүй. Миний шүүлт бол хүнийг Надад илүү дуулгавартай болгохын төлөө, Миний гэсгээлт бол илүү үр дүнтэй өөрчлөгдөх боломжийг хүнд олгохын төлөө юм. Миний хийдэг зүйл Миний удирдлагын төлөө байдаг хэдий ч хүнд ашиг тусгүй зүйл хийж байсан удаа Надад ер үгүй билээ. Үүний учир нь Би Израилийн гаднах бүх үндэстнийг яг л израильчууд шиг дуулгавартай болгож, тэднийг жинхэнэ хүн болгохыг хүсдэг, ингэснээр Би Израилийн гаднах газар нутагт түшиц газартай болох юм. Энэ бол Миний удирдлага; энэ бол Харь үндэстнүүдийн дунд Миний хэрэгжүүлж буй ажил юм. Одоо ч гэсэн Миний удирдлагыг олон хүн ойлгохгүй л байдаг, учир нь тэд эдгээр зүйлийг огт сонирхдоггүй, гагцхүү өөрсдийнхөө ирээдүй болон хүрэх газарт л санаа тавьдаг. Намайг юу ч хэлсэн байсан тэд Миний хийдэг ажлыг тоосон шинжгүй хэвээрээ л байж, харин ирээдүйд хүрэх газартаа л гагцхүү анхаарлаа төвлөрүүлдэг. Хэрвээ байдал энэ янзаар үргэлжлээд байвал Миний ажил яаж өргөжиж чадах юм бэ? Миний сайн мэдээ яаж дэлхий даяар түгж чадах юм бэ? Миний ажил түгэх үед Би та нарыг бутаргана, мөн Ехова Израилийн овог бүрийг бут ниргэсэнтэй адилаар Би та нарыг бут ниргэнэ гэдгийг мэдэж ав. Өөрийн сайн мэдээг газар дэлхий даяар түгээж, Өөрийн ажлыг Харь үндэстэн рүү өргөжүүлж, томчуул, хүүхдүүд ялгаагүй Миний нэрийг алдаршуулдаг, Миний ариун нэрийг бүх овог, үндэстний хүмүүс ам амандаа магтан өргөмжилдөг болгохын тулд энэ бүхнийг хийнэ. Ингэснээр энэхүү төгсгөлийн эринд Миний нэр Харь үндэстнүүдийн дунд алдаршиж, Миний үйл хэргийг Харь үндэстнүүд харж, үйл хэргийн минь улмаас тэд Намайг Төгс Хүчит гэж дуудах бөгөөд Миний үг удалгүй биелэх болно. Би бол израильчуудын цор ганц Бурхан төдийгүй, бүх Харь үндэстний, тэр ч байтугай хараасан үндэстнүүдийнхээ ч Бурхан гэдгээ Би бүх хүнд мэдүүлнэ. Би бол бүх бүтээлийн Бурхан гэдгээ бүх хүнд харуулна. Энэ бол Миний хамгийн агуу ажил, эцсийн өдрүүдийн ажлын төлөвлөгөөний минь зорилго ба эцсийн өдрүүдэд биелүүлэх цорын ганц ажил юм.

Хэдэн мянган жилийн турш Миний удирдсаар ирсэн ажил эцсийн өдрүүдэд л хүнд бүрэн илчлэгддэг. Одоо л Би хүнд Өөрийн удирдлагын нууцыг бүрэн нээж байгаа бөгөөд Хүн Миний ажлын зорилгыг мэдэж аваад зогсохгүй, Миний бүх нууцын талаар ойлголттой болсон. Санааг нь зовоодог хүрэх газрынх нь тухай бүх зүйлийг Би хүнд хэлсэн. 5,900 гаруй жилийн турш далдалж байсан Өөрийнхөө бүх нууцыг Би аль хэдийн хүнд дэлгэсэн. Ехова гэж хэн бэ? Мессиа гэж хэн бэ? Есүс гэж хэн бэ? Та нар энэ бүхнийг мэдэх ёстой. Миний ажлын эргэлтийн цэг энэ хэдэн нэрд бий. Та нар үүнийг ойлгов уу? Миний ариун нэрийг хэрхэн тунхаглах ёстой вэ? Намайг аль нэг нэрээр минь дуудаж гуйдаг үндэстнүүдэд Миний нэрийг хэрхэн түгээх ёстой вэ? Миний ажил өргөжиж байгаа бөгөөд Би ажлаа аливаа бүх үндэстэнд бүхэлд нь түгээнэ. Миний ажил та нарын дотор нэгэнт хэрэгжсэн тул Ехова Израилд Давидын гэрийн хоньчдыг бут ниргэсэнтэй адилаар Би та нарыг бут

ниргэж, үндэстэн бүрийн дунд тараан бутаргана. Учир нь, эцсийн өдрүүдэд Би бүх үндэстнийг хэдэн хэсэг бутартал нь няц дарах бөгөөд ард түмнийг нь шинээр хуваарилна. Намайг дахин эргэж ирэхэд үндэстнүүд Миний дүрэлзэх галаар тогтоосон хилээр аль хэдийн хуваагдчихсан байх болно. Тэр үед Би хүн төрөлхтөнд Өөрийгөө төөнөх нар мэт шинээр илэрхийлж, тэдний хэзээ ч харж байгаагүй Ариун Нэгний дүрээр Өөрийгөө ил тод харуулж, урьд Ехова Би Иудейн овгуудын дунд алхаж байсантайгаа адилаар үй олон үндэстний дунд алхана. Тэр цагаас эхлэн Би газар дээрх хүн төрөлхтний амьдралыг зална. Тэнд тэд Миний алдар сууг гарцаагүй харах ба өөрсдийнх нь амьдралыг залж чиглүүлэх агаар дахь үүлэн баганыг харах нь гарцаагүй, учир нь Би ариун газарт илрэх болно. Хүн Миний зөвт байдлын өдрийг, түүнчлэн Миний алдар суут илрэлийг харна. Тэр нь Би газар дээр ноёрхол тогтоож, Өөрийн олон хөвгүүнийг алдар суу руу аваачих үе байх болно. Газар дээрх хүмүүс хаа сайгүй мэхийх бөгөөд Миний асрыг хүн төрөлхтний дунд, Миний өнөөдрийн хэрэгжүүлж буй ажлын хадан дээр бат бэх босгоно. Хүмүүс бас сүмд Надад үйлчилнэ. Бохир, жигшүүрт зүйлсэд дарагдсан тахилын ширээг Би яйртал цохиод шинээр хийнэ. Нялх хурга, тугалуудыг ариун тахилын ширээн дээр овоолно. Би өнөөдрийн сүмийг буулгаад шинийг барина. Зэвүүн хүмүүсээр дүүрсэн, одоо байгаа сүм нурах бөгөөд Миний барьсан сүм Надад үнэнч зарц нараар дүүрнэ. Тэд Миний сүмийн суу алдрын төлөө дахин нэг өндийн босож, Надад үйлчилнэ. Намайг агуу алдар суу хүртэх тэр өдрийг та нар гарцаагүй харах ба Би хуучин сүмийг буулгаад шинийг барих тэр өдрийг ч гарцаагүй харна. Түүнчлэн Миний асар хүний ертөнцөд хүрч ирэх тэр өдрийг та нар гарцаагүй харна. Би сүмийг хэмх цохимогцоо Намайг бууж ирэхийг харах хүмүүсийн нүдэн дээр Өөрийнхөө асрыг хүний ертөнцөд авчирна. Бүх үндэстнийг бут цохисныхоо дараа Би тэднийг нэг дор шинээр цуглуулж, тэр цагаас Өөрийн сүмийг барьж, Өөрийн тахилын ширээг тавина, тэгснээр бүгд Надад тахил өргөж, Миний сүмд Надад үйлчилж, Харь үндэстэн дэх Миний ажилд өөрсдийгөө үнэнчээр зориулах болно. Тэд өнөөгийн израилчууд шиг тахилчийн өмсгөл, титмээр гоёх ба Ехова Миний алдар суу тэдний дунд дуурьсаж, Миний сүр жавхлан тэдний дээр эргэлдэж, тэдэнтэй хамт орших болно. Харь үндэстнүүд дэх Миний ажил ч бас ийм маягаар гүйцэлдэнэ. Харь үндэстнүүд дэх Миний ажил Израилд хийсэн Миний ажил шиг байх болно, яагаад гэвэл, Би Израил дахь ажлаа өргөжүүлж, үүнийгээ Харь үндэстнүүдэд түгээх юм.

Одоо үе бол Миний Сүнс агуу зүйлс хийж буй цаг бөгөөд Би Харь үндэстнүүдийн дунд Өөрийн ажлыг эхэлж буй цаг билээ. Түүгээр ч зогсохгүй, одоо бол Миний бүх бүтээгдсэн зүйлийг ангилж, нэг бүрийг нь тус тусын ангилалд нь хуваарилах цаг юм, ингэснээр Миний ажил илүү түргэн, илүү үр дүнтэй явагдах болно. Иймээс бүхий л оршихуйгаа Миний бүх ажилд өргөн барьж, цаашлаад чамд хийсэн Миний бүх ажлыг тодорхой ялган таньж, итгэлтэй болж, Миний ажлыг илүү сайн үр дүнд хүргэхийн тулд бүх хүч чадлаа зориулаач гэж л Би та нараас шаарддаг. Энэ бол

чиний ойлгох ёстой зүйл юм. Өөр хоорондоо тэмцэлдэж, буцах зам хайж эсвэл махан биеийн тав тух хөөцөлдөхөөс татгалз, эдгээр нь Миний ажлыг хойшлуулах ба гайхалтай ирээдүйг чинь баллах болно. Тэгэх нь чамд хамгаалалт өгөх нь байтугай харин ч сүйрэл авчирна. Тэгвэл тэнэглэж байгаа хэрэг болох бус уу? Өнөөдөр чиний шуналтайгаар эдлэн буй зүйлс чинь ирээдүйг чинь яг баллаж буй юм, харин өнөөдөр чиний амсаж буй зовлон чинь л чамайг яг хамгаалж буй билээ. Мултарч гарахад хэцүү уруу таталтад урхидуулахаас булташ, төөрөлдөж яваад өтгөн мананд ороод нарыг олж чадахгүй болохоос зайлсхийхийн тулд чи эдгээр зүйлийг тодорхой мэдэж байх ёстой. Өтгөн манан сарнихад чи агуу өдрийн шүүлтэд орсноо мэднэ. Тэр үед Миний өдөр хүн төрөлхтөнд ойртсон байх болно. Чи Миний шүүлтээс яаж зугтах юм бэ? Төөнөх нарны халууныг чи яаж тэсэх юм бэ? Миний хайрласан элбэг хангалуун бүхнийг хүн цээжиндээ нандигнахын оронд хэний ч анзаарахааргүй газарт хаядаг. Миний өдөр хүн дээр буух үед хүн элбэг дэлбэг байдлыг минь олж чадахаа болино, эсвэл аль эрт өөрт нь хэлсэн үнэний гашуун үгийг минь ч олж чадахаа болино. Тэрээр гэрлийн гэгээг алдаж, харанхуйд унасан учраас уйлж, орилно. Өнөөдөр та нар ердөө л Миний аман дахь хурц илдийг харж байна. Та нар Миний гартаа барьж буй таяг, эсвэл хүнийг шатаадаг дөлийг минь хараахан үзээгүй байгаа, тийм учраас л та нар одоо ч гэсэн Миний өмнө хямсгар, цадиггүй загнадаг. Тийм болохоор л та нар одоо ч гэсэн гэрт минь Надтай тэмцэлдэж, Миний амаараа хэлсэн зүйлтэй өөрийн хүний хэлээр маргадаг. Хүн Надаас айдаггүй, өнөөдрийг хүртэл Надтай дайсагнасаар ирсэн хэр нь бас л ямар ч айдасгүй байдаг. Та нар амандаа зөв шударга бусын хэл ба шүдтэй. Та нарын үг болон үйл хэрэг Еваг нүгэлд уруу татсан могойнхтой адилхан. Та нар бие биедээ нүдийг нүдээр, шүдийг шүдээр төлдөг бөгөөд өөртөө байр суурь, нэр алдар, ашиг хонжоо булааж авах гэж Миний дэргэд тэмцэлддэг, гэхдээ Би үг, үйл хэргийг чинь сэмхэн ажиглаж байгааг мэддэггүй. Та нарыг Миний дэргэд ирэхээс ч өмнө Би зүрх сэтгэлийн чинь хамгийн гүнийг чагнан мэдсэн. Хүн Миний атгаас мултарч, Миний нүдний ажиглалтаас бултахыг үргэлж хүсдэг боловч Би түүний үг, үйл хэргээс хэзээ ч далдирч байгаагүй. Харин ч тэдгээр үг, үйл хэргийг зориуд хараандаа тусгадаг, ингэснээр Би хүний зөв шударга бус байдлыг гэсгээж, түүний тэрслүү занг шүүж чадна. Тиймээс хүний далд үг, үйл хэрэг үргэлж Миний шүүх суудлын өмнө байж байдаг ба хүний тэрслүү чанар дэндүү их учраас Би хүнийг шүүхээ хэзээ ч зогсоож байгаагүй. Миний ажил бол Миний Сүнсний дэргэд хүний хэлсэн үг, хийсэн ажлыг бүгдийг шатааж, ариусгах явдал юм. Ийнхүү[a], Намайг дэлхийгээс одсон ч хүмүүс Надад үнэнч хэвээр үлдэх ба ариун зарц нарын минь Надад үйлчилдгийн адилаар үйлчилж, газар дээрх Миний ажилд бүрэн төгс болох өдрөө хүртэл үргэлжлэх боломжийг бүрдүүлнэ.

[a] Эх бичвэрт “Ийнхүү” гэдэг үг байдаггүй.

ТА НАР БҮГД МАШ ЖУДАГГҮЙ!

Та нар бүгд дэгжин суудалд сууж, өөрсөдтэйгээ адил төрлийн залуу үеийнхэнд зааж сурган, тэднийг бүгдийг нь өөртэйгээ хамт суулгадаг. “Үр удам” чинь аль хэдийн амьсгаагүй болж, Миний ажлыг алдсан гэдгийг та нар огт мэддэггүй. Миний алдар суу Зүүн зүгийн газар нутгаас баруун зүгийн газар нутаг хүртэл гялбуулдаг боловч ертөнцийн зах хязгаар хүртэл тархаад, урган гарч, гэрэлтэж эхлэх үед нь Би Зүүний алдраа буцаан авч, баруун зүгт аваачна, ингэснээр Зүүн зүгт Намайг орхисон, харанхуйн хүмүүс тэр цагаас эхлээд гэрэлтүүлэлтээс хагацна. Тэр үед та нар сүүдэрт хөндийд амьдарна. Хэдийгээр өнөөгийн хүмүүс өмнөхөөсөө зуу дахин илүү дээр боловч Миний шаардлагад нийцэж чадахгүй хэвээр байгаа ба Миний алдрын гэрчлэл биш хэвээр байгаа. Та нар урьдынхаасаа зуу дахин илүү дээр байж чадаж байгаа нь бүхэлдээ Миний ажлын үр дүн юм; энэ нь газар дээрх Миний ажлаас бий болсон үр жимс билээ. Гэвч Би та нарын үг, үйл хэрэг, түүнчлэн ёс жудгийг үзэн ядсаар байдаг бөгөөд Миний өмнө гаргаж байгаа үйлдэлд чинь туйлын их дургүйцдэг, учир нь та нарт Миний талаар ямар ч ойлголт байдаггүй. Тэгвэл та нар яаж Миний алдрыг амьдран харуулж, яаж Миний хожмын ажилд туйлын үнэнч байж чадах юм бэ? Та нарын итгэл маш сайхан; та нар бүх амьдралаа Миний ажлын төлөө зарлагадаж, үүний төлөө амьдралаа золиослоход бэлэн гэж хэлдэг боловч зан чанар чинь тийм ч их өөрчлөгдөөгүй. Бодит ааш авир чинь тун өөдгүй гэх баримтыг үл харгалзан та нар биеэ тоосон байдлаар ярьдаг. Хүмүүсийн хэл болон уруул тэнгэрт байдаг хэдий ч хөл нь хаа хол газар дээр байгаа мэт байдаг бөгөөд үүний үр дүнд тэдний үг, үйл хэрэг, нэр төр гутамшигтай хэвээр байдаг. Та нарын нэр төр сүйрч, намба төрх чинь доройтсон, ярьж байгаа байдал чинь дорд, амьдрал чинь жигшүүртэй, тэр ч бүү хэл, хүн чанар чинь тэр чигтээ олиггүй дорд болсон. Та нар бусдад явцуу сэтгэлээр ханддаг бөгөөд жижиг сажиг юм бүр дээр маргалддаг. Та нар нэр төр, байр сууриасаа болж там руу, галт нуур луу унахад ч бэлэн байх хэмжээнд хүртлээ хэрэлдэж муудалцдаг. Одоогийн үг болон үйл хэрэг чинь та нарыг нүгэлтэй гэж тодорхойлоход минь хангалттай. Миний ажилд хандах хандлага чинь та нарыг зөв шударга бус хүмүүс гэж тодорхойлоход минь хангалттай бөгөөд жигшил зэвүүцлээр дүүрэн бузар сүнснүүд гэдгийг чинь харуулахад зан чанар чинь хангалттай. Та нарын харуулж, илчилж байгаа зүйл та нарыг бузар сүнсний цусыг ханатлаа уусан хүмүүс гэж хэлэхэд хангалттай байдаг. Хаанчлалд орох тухай дурдах үед та нар мэдрэмжээ илчилдэггүй. Одоо байгаа байдал чинь Миний тэнгэрийн хаанчлалын хаалгаар ороход хангалттай гэж та нар бодож байна уу? Үг болон үйл хэрэг чинь эхлээд Миний туршилтыг туулахгүйгээр та нар Миний ажил болон үгийн ариун газарт орж чадна гэж итгэж байна уу? Миний хоёр нүдийг хэн хууран мэхэлж чадах юм бэ? Та нарын жигшүүртэй, дорд ааш авир болон яриа яаж Миний харцнаас зайлж чадах юм бэ? Та нарын амьдралыг Би тэдгээр бузар сүнсний цусыг ууж, махыг идэх

амьдрал хэмээн тодорхойлсон, учир нь та нар Миний өмнө өдөр бүр тэднийг дуурайдаг. Миний өмнө та нарын зан авир тун муу байсаар ирсэн болохоор Би яаж зэвүүцэхгүй байж чадах юм бэ? Та нарын үг бузар сүнсний хольцыг агуулдаг: Та нар хар шид хийдэг хүмүүсийн адилаар, мөн тэрслүү агаад зөвт бусын цусыг уудаг хүмүүсийн адилаар аргалж, нуун далдалж, зусарддаг. Хүний бүх илэрхийлэл туйлын зөв шударга бус байдаг тул зөв шударга хүмүүсийн байдаг ариун газарт яаж бүх хүнийг байрлуулж болох юм бэ? Жигшүүртэй зан авир чинь чамайг зөвт бус хүмүүстэй харьцуулахад ариун хэмээн ялгаж чадна гэж чи бодож байна уу? Могойнх шиг хэл чинь, сүйрэл учруулж, зэвүүцэл төрүүлдэг энэ махан биеийг чинь эцэст нь мөхөөх бөгөөд бузар сүнсний цусаар хучигдсан гар чинь ч бас эцэст нь чиний сүнсийг там руу чангаана. Тэгвэл чи бузраар хучигдсан гараа цэвэрлэхийн тулд яагаад энэ боломжийг шүүрэн авахгүй гэж? Зөв шударга бус үг хэлдэг хэлээ таслахын тулд чи яагаад энэ боломжийг ашиглахгүй гэж? Өөрийнхөө хоёр гар, хэл болон уруулын төлөө чи тамын галд зовоход бэлэн байгаа юм гэж үү? Хүн төрөлхтнийг бүтээхээсээ хавьгүй өмнө зүрх сэтгэлийг нь гартаа атгаж байсан учраас Би хүн бүрийн зүрх сэтгэлийг хоёр нүдээрээ ажигладаг. Би хүмүүсийн зүрх сэтгэлийг аль эртнээс нэвт шувт харсан тул тэдний бодол санаа Миний харцнаас зайлж яахан чадах билээ? Тэд Миний Сүнсний шатаалтаас зугтаж яахан амжих билээ?

Уруул чинь тагтааныхаас илүү зөөлөн боловч зүрх сэтгэл чинь эртний могойныхоос ч илүү хорлонтой. Уруул чинь бүр Ливан эмэгтэйчүүдийнх шиг сайхан боловч зүрх сэтгэл чинь тэднийхээс эелдэг зөөлөн биш бөгөөд мэдээж канаанчуудын гоо үзэсгэлэнтэй харьцуулахын аргагүй. Чиний зүрх сэтгэл маш хорон санаатай! Би зөв шударга бус хүний уруул болон зүрх сэтгэлийг л үзэн яддаг бөгөөд хүмүүст тавих Миний шаардлага ариун хүмүүсээс шаарддагаас минь огтхон ч өндөр биш; Би зүгээр л зөв шударга бус хүний ёрын муу үйл хэргийг зэвүүцдэг бөгөөд тэрээр бузар заваан байдлаа хаяж, одоогийн төвөгтэй байдлаасаа зугтаж, ингэснээрээ зөв шударга бус хүмүүсээс ялгаран, зөв шударга хүмүүстэй хамт амьдарч, ариун байж чадна гэж найддаг. Та нар Надтай адил орчин нөхцөлд байгаа мөртөө бузраар бүрхэгдсэн; анх бүтээгдсэн хүмүүсийн анхдагч төрх та нарт өчүүхэн төдий ч байхгүй. Түүнчлэн, та нар өдөр болгон тэдгээр бузар сүнсний төрхийг дуурайн, тэдний хийдэг зүйлийг хийж, хэлдэг зүйлийг хэлдэг учраас бүх хэсэг, бүр хэл, уруулд чинь хүртэл тэдний бохир ус нэвчин, та нар бүхэлдээ тийм хир толбоор хучигдахдаа тулсан бөгөөд ганц ч хэсгийг чинь Миний ажилд ашиглаж болдоггүй. Үнэхээр зүрх шимшрэм! Та нар үхэр, адууны ийм ертөнцөд амьдардаг атал та нарт үнэндээ төвөгтэй санагддаггүй; баяр хөөрөөр дүүрэн байж, эрх чөлөөтэй, амар хялбараар амьдардаг. Тэрхүү бохир усанд сэлж байгаа мөртөө ийм төвөгтэй байдалд орсон гэдгээ үнэндээ ухаардаггүй. Өдөр бүр чи бузар сүнсийг дагалдаж, “ялгадастай” харилцдаг. Амьдрал чинь нэлээд дорд атал чи, хүний ертөнцөд огтхон ч оршдоггүй, мөн өөрийгөө хянадаггүй гэдгээ үнэндээ мэддэггүй. Чиний амьдралыг тэр бузар сүнснүүд аль хэдийн гишгэлээд, ёс жудгийг чинь бохир ус аль хэдийн

сэвтээсэн гэдгийг чи мэдэхгүй гэж үү? Чи газар дэлхийн диваажинд амьдарч, аз жаргалтай байгаа гэж бодож байна уу? Бузар сүнснүүдтэй хамт амьдарч, чамд зориулан тэдний бэлдсэн бүх зүйлтэй зэрэгцэн оршсон гэдгээ чи мэдэхгүй гэж үү? Чиний амьдардаг байдал яаж утга учиртай байж чадах юм бэ? Чиний амьдрал яаж үнэ цэнтэй байж чадах юм бэ? Чи бузар сүнс эцэг эхийнхээ төлөө ийш тийш завгүй гүйсээр ирсэн мөртөө чамайг урхидагчид нь чамайг төрүүлж, өсгөсөн бузар сүнс эцэг эх чинь гэдгийг огт мэддэггүй. Түүнчлэн, бүх бузар буртгийг чинь үнэндээ тэд чамд өгсөн гэдгийг чи мэддэггүй; тэд чамд “таашаал” өгдөг, чамайг гэсгээдэггүй, мөн шүүдэггүй бөгөөд ялангуяа чамайг хараадаггүй гэдгийг л чи мэднэ. Тэд хэзээ ч чамд дэлбэртлээ уурладаггүй, харин хайраар, эелдгээр ханддаг. Тэдний үг зүрх сэтгэлийг чинь тэжээж, чиний хайрыг булаадаг болохоор чи толгой нь эргэсэн байдалтай болж, өөрийн мэдэлгүй тэдэнд татагдаж, үйлчлэн, тэдний гарц, бас зарц болоход бэлэн байдаг. Чамд ямар ч гомдол байдаггүй, харин тэдний төлөө морь нохой мэт зүтгэхэд бэлэн байдаг; чи тэдэнд мэхлэгддэг. Ийм учраас чи Миний хийдэг ажилд бүр ямар ч хариу үйлдэл үзүүлдэггүй. Чи Миний гараас нууцаар мултрахыг үргэлж хүсдэгт гайхах юмгүй бөгөөд Миний ивээлийг овжноор олж авахын тулд нялуун үг хэрэглэхийг үргэлж хүсдэгт чинь гайхах юмгүй. Чамд аль хэдийн өөр нэг төлөвлөгөө, өөр нэг зохицуулалт байгаа болж таардаг. Чи Төгс Хүчит Миний үйлдлүүдийн багахныг харж чадах боловч Миний шүүлт, гэсгээлтийг өчүүхэн ч мэддэггүй. Миний гэсгээлт хэзээ эхэлснийг чи огт мэддэггүй; Намайг хэрхэн хуурахаа л мэддэг ч Би хүний ямар ч халдлагыг тэвчихгүй гэдгийг мэддэггүй. Чи аль хэдийн Надад үйлчлэх шийдвэр гаргасан тул Би чамайг тавьж явуулахгүй. Би бол хартай Бурхан бөгөөд хүнийг харддаг Бурхан билээ. Нэгэнт чи өөрийн үгийг тахилын ширээн дээр аль хэдийн тавьсан тул яг нүдний минь өмнүүр зугтаан одохыг чинь Би тэвчихгүй, хоёр эзэнд үйлчлэхийг чинь ч тэвчихгүй. Өөрийнхөө үгийг Миний тахилын ширээн дээр, хоёр нүдний минь өмнө тавьсны дараа чамд өөр нэг хайр байж болно гэж чи бодоо юу? Тийм маягаар Намайг тэнэгтүүлэхийг Би яаж хүмүүст зөвшөөрч чадах юм бэ? Чи өөрийнхөө хэлээр Надад хааш яаш андгай, тангараг тавьж болно гэж бодоо юу? Чи Хамгийн Дээд Миний сэнтийгээр тангараглаж яаж чадах юм бэ? Чиний тангараг аль хэдийн алга болсон гэж чи бодоо юу? Би та нарт хэлье: Та нарын махан бие нас барж болох ч тангараг чинь үгүй болохгүй. Эцэст нь Би тангарагт чинь үндэслэн та нарыг яллана. Гэсэн ч Намайг аргалахын тулд та нар өөрсдийн үгийг Миний өмнө тавиад зүрх сэтгэлээрээ бузар сүнс болон муу ёрын сүнсэнд үйлчилж болно гэж боддог. Намайг хуурдаг тэр нохой, гахай шиг хүмүүсийг Миний уур хилэн яаж тэвчиж чадах юм бэ? Би Өөрийн захиргааны зарлигийг гүйцэтгэж, Надад итгэдэг тэр бүх ёсорхуу, “чин сүсэгт” хүмүүсийг бузар сүнснүүдийн гараас булаан авах ёстой ба ингэснээр тэд дэг журамтай байдлаар Надад “үйлчилж”, Миний шар үхэр, Миний адуу болж, Миний нядалгааны эрхээр байж магад юм. Би чамаар өмнөх шийдвэрийг чинь сэргээлгэж, Өөртөө дахин нэгэнтээ үйлчлүүлнэ. Намайг хууран мэхэлдэг ямар ч бүтээлийг Би

тэвчихгүй. Чи Миний өмнө дур зоргоороо хүсэлт тавьж, худал хэлж болно гэж бодсон уу? Би чиний үг болон үйл хэргийг сонсоогүй, эсвэл хараагүй гэж бодсон уу? Чиний үг, үйл хэрэг яаж Надад харагдахгүй байж чадах юм бэ? Хүмүүс Намайг тийнхүү мэхлэхийг Би яаж ер нь зөвшөөрч чадах юм бэ?

Би та нарын дунд байж, хэд хэдэн хавар, намрын турш та нартай харилцсан; Би та нарын дунд удаан хугацаанд амьдарч, та нартай хамт амьдарсан. Та нарын жигшүүртэй зан авирын хэр их нь яг Миний нүдний өмнүүр булталсан бэ? Та нарын үнэн сэтгэлийн үг Миний чихэнд тасралтгүй цуурайтаж байна; та нарын сая сая хүсэл эрмэлзэл Миний тахилын ширээн дээр тавигдсан—бүр тоолохын ч аргагүй дэндүү олон. Гэсэн ч та нарын зориулалт болон зарлагадсан зүйл өчүүхэн төдий ч байдаггүй. Миний тахилын ширээн дээр та нар жаахан ч болов чин сэтгэл тавьдаггүй. Надад итгэх итгэлийн чинь үр жимс хаана байна вэ? Та нар Надаас эцэс төгсгөлгүй нигүүлсэл хүлээн авч, тэнгэрийн эцэс төгсгөлгүй нууцуудыг харсан; тэр ч байтугай Би та нарт тэнгэрийн гал дөлийг харуулсан боловч та нарыг шатаах сэтгэл Надад байгаагүй. Гэсэн ч хариуд нь та нар Надад хэр ихийг өгсөн бэ? Надад хэр ихийг өгөхөд бэлэн байна вэ? Миний чамд өгсөн хоолыг гартаа бариад чи эргэж, үүнийгээ Надад өргөдөг, тэр ч бүү хэл шаргуу ажлынхаа хөлсөнд олсон зүйл чинь энэ бөгөөд байгаа бүхнээ Надад өргөн барьж байна гэж ч хэлдэг. Надад өгч буй “хувь нэмэр” чинь бүгд Миний тахилын ширээнээс хулгайлагдсан зүйл гэдгийг чи яаж мэдэхгүй байх юм бэ? Түүнчлэн, одоо үүнийг Надад өргөн барьж байгаа чинь Намайг мэхэлж байгаа хэрэг бус уу? Өнөөдөр Би, шаргуу ажлынхаа хариуд чиний олж, Надад өргөн барьсан зүйлийг биш, харин Өөрийн тахилын ширээн дээрх бүх тахилыг эдэлдэг гэдгийг чи яаж мэдэхгүй байх юм бэ? Та нар үнэндээ ийм маягаар Намайг хуурч зүрхэлдэг тул Би яаж та нарыг өршөөж чадах юм бэ? Би үүнийг цаашид яаж тэвчиж чадах юм бэ? Би бүхнийг та нарт өгсөн. Би та нарт бүхнийг нээж, хэрэгцээг чинь хангаж, нүдийг чинь нээсэн атал та нар Намайг ийм маягаар мэхэлж, мөс чанараа үл ойшоодог. Би амь биеэ үл хайрлан бүх зүйлийг та нарт хайрласан болохоор хэдий та нар зовдог ч тэнгэрээс Миний авчирсан бүхнийг Надаас мөн л олж авсан. Гэсэн ч та нарт ямар ч зориулалт байхгүй бөгөөд өчүүхэн жаахан хувь нэмэр оруулсан ч гэсэн дараа нь та нар Надтай “тооцоо хийхээр” оролддог. Чиний хувь нэмэр юу ч үгүйтэй адил биш гэж үү? Надад өгсөн зүйл чинь элсний ширхэг төдий боловч Надаас гуйсан зүйл чинь нэг тонн алт юм. Чи зүгээр л бодлогогүй байгаа бус уу? Би та нарын дунд ажилладаг. Өөр нэмэлт тахил байтугай, Надад өгөх ёстой аравны нэгийн ул мөр ч огт байдаггүй. Үүнээс гадна, үнэн сүсэгт хүмүүсийн өргөсөн аравны нэгийг ч хорон муу нэгэн булаан авдаг. Та нар бүгд Надаас холдон тараагүй гэж үү? Та нар бүгд Надтай дайсагнадаггүй гэж үү? Та нар бүгд Миний тахилын ширээг сүйтгэж байгаа биш үү? Ийм хүмүүс яаж Миний нүдэнд эрдэнэс шиг харагдаж чадах юм бэ? Тэд Миний үзэн яддаг гахай, нохой биш гэж үү? Та нарын муу үйлийг Би яаж эрдэнэс гэж хэлж чадах юм бэ? Миний ажил үнэндээ хэний төлөө хийгддэг вэ? Өөрийн эрх мэдлийг илчлэхийн тулд

та нарыг бүгдийг нь цохин унагах л зорилготой байдаг юм гэж үү? Та нарын амьдрал бүгд Надаас гарах ганцхан үгэн дээр тогтдоггүй гэж үү? Яагаад Би та нарт зааварлахын тулд үгийг л ашиглаад, та нарыг аль болох хурдан цохин унагаахын тулд үгийг бодит баримт болгон хувиргахгүй байгаа юм бэ? Миний үг болон ажлын зорилго ердөө хүн төрөлхтнийг цохин унагаахын төлөө байдаг уу? Би гэмгүй хүнийг ялгаварлахгүйгээр хөнөөдөг Бурхан гэж үү? Яг одоо хүний амьдралын зөв замыг эрж хайхын тулд та нарын хэчнээн нь бүхий л оршихуйгаараа Миний өмнө ирж байна вэ? Миний өмнө та нарын бие л байдаг; зүрх сэтгэл чинь мөн л эрх дураараа, Надаас холын холд байдаг. Миний ажил үнэндээ юу болохыг мэддэггүй учраас та нарын зарим нь Намайг орхин одож, өөрсдийгөө Надаас холдуулж, ямар ч гэсгээлт, шүүлт байдаггүй диваажинд амьдрахаар найддаг. Энэ нь хүмүүсийн зүрх сэтгэлдээ хүсдэг зүйл биш гэж үү? Би мэдээж чамайг албадахаар оролдоогүй. Ямар замаар явах чинь чиний өөрийн сонголт. Өнөөдрийн зам нь шүүлт, хараал дагалддаг зам боловч та нарт Миний хайрласан бүхэн—шүүлт ч бай, эсвэл гэсгээлт ч бай хамаагүй, Миний өгч чадах хамгийн сайхан бэлэг бөгөөд та нарт яаралтай хэрэгтэй бүх зүйл юм гэдгийг та нар бүгд мэдэх ёстой.

ХУУЛИЙН ЭРИН ҮЕ ДЭХ АЖИЛ

Израильчууд дээр хийсэн Еховагийн ажил нь газар дээрх Бурханы эх нутаг буюу Түүний байдаг ариун газрыг хүн төрөлхтний дунд байгуулжээ. Тэрээр Өөрийн ажлыг Израилийн ард түмнээр хязгаарласан юм. Эхэндээ Тэр Израилийн гадна ажиллаагүй, харин ажлынхаа цар хүрээг хязгаарлахын тулд тохиромжтой гэж үзсэн хүмүүсээ сонгон авчээ. Израиль бол Бурхан Адам, Ева хоёрыг бүтээсэн газар бөгөөд тэрхүү газрын шорооноос Ехова хүнийг бүтээсэн; энэ газар нь газар дэлхий дээрх Түүний ажлын үндэс болсон юм. Ноагийн, бас Адамын үр удам болох израильчууд нь газар дээрх Еховагийн ажлын суурь хүмүүс байсан билээ.

Тухайн үед, Израиль дахь Еховагийн ажлын ач холбогдол, зорилго, алхмууд нь Өөрийн ажлыг дэлхий даяар эхлүүлэх буюу Израилийг төвөө болгон аажмаар Харь үндэстнүүд рүү түгэх явдал байлаа. Энэ бол орчлон ертөнц даяар ажиллахдаа Түүний баримталдаг зарчим—загвар байгуулаад дараа нь орчлон ертөнцийн бүх хүн сайн мэдээг нь хүлээн авах хүртэл загвараа өргөжүүлэх явдал мөн. Эхний израильчууд Ноагийн үр удам байв. Энэ хүмүүст зөвхөн Еховагийн амьсгал өгөгдсөн ба тэд амьдралын үндсэн хэрэгцээгээ хангахуйц зүйлийг ойлгож байсан боловч Ехова ямархуу Бурхан болохыг, хүний төлөөх Түүний хүсэл юу болохыг мэдээгүй, бүх бүтээлийн Эзэнийг хэрхэн хүндэтгэх ёстойгоо бүр ч мэдээгүй. Дуулгавартай дагах[a] дүрэм журам, хууль байсан эсэх, эсвэл бүтээгдсэн зүйл нь

[a] Эх бичвэрт “дуулгавартай дагах” гэх хэллэг байдаггүй.

Бүтээгчийн төлөө хийх ёстой үүрэг байсан эсэх тухайд бол, Адамын үр удам эдгээрийн алийг ч мэддэггүй байлаа. Гэр бүлээ тэжээхийн тулд эр нөхөр нь хөлсөө урсган хөдөлмөрлөж, эхнэр нь нөхөртөө захирагдаж, Еховагийн бүтээсэн хүн төрөлхтнийг үргэлжлүүлэх ёстой гэдгийг л тэд мэддэг байв. Өөрөөр хэлбэл, Еховагийн амьсгал болон амийг л агуулж байсан ийм хүмүүс Бурханы хуулийг хэрхэн дагахыг, эсвэл бүх бүтээлийн Эзэнийг хэрхэн сэтгэл хангалуун байлгахыг мэддэггүй байжээ. Тэд дэндүү багыг ойлгодог байлаа. Иймээс, хэдийгээр тэдний зүрх сэтгэлд гажууд, ов мэхтэй зүйл юу ч байгаагүй, тэдний дунд атаархал, хэрүүл тэмцэл хаяахан гардаг байсан ч тэд бүх бүтээлийн Эзэн Еховаг мэддэггүй, ойлгодоггүй байв. Хүний эдгээр өвөг дээдэс зөвхөн Еховагийн зүйлийг идэж, Еховагийн зүйлийг эдлэхийг л мэддэг байсан боловч Еховаг хэрхэн хүндлэхийг мэддэггүй байжээ; Ехова бол өвдөг сөгдөн шүтэн мөргөх ёстой Нэгэн гэдгийг тэд мэддэггүй байлаа. Иймээс тэднийг яаж Түүний бүтээл гэж нэрлэж болох юм бэ? Хэрвээ тэгсэн бол “Ехова бол бүх бүтээлийн Эзэн” болон “Тэрээр Өөрийгөө харуулж, Өөрийгөө алдаршуулж, Өөрийгөө төлөөлүүлэхээр хүнийг бүтээсэн” гэдэг үгийг хий дэмий хэлсэн болох бус уу? Еховаг огт хүндэлдэггүй хүмүүс яаж Түүний алдрын гэрчлэл болж чадах юм бэ? Тэд яаж Түүний алдрын илрэл болж чадах юм бэ? Тэгвэл “Би хүнийг Өөрийн дүрээр бүтээсэн” гэх Еховагийн үг, муу ёрын нэгэн болох Сатаны гар дахь зэвсэг болох бус уу? Тэгвэл эдгээр үг нь Ехова хүнийг бүтээсний ичгүүрийн тэмдэг болох бус уу? Ажлын тэрхүү үе шатыг гүйцэлдүүлэхийн тулд Ехова хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа Адамаас эхлээд Ноаг хүртэл тэдэнд зааварчилж, залж чиглүүлээгүй юм. Харин ч үерээр дэлхийг устгасны дараа л Тэр, Ноа болон бас Адамын үр удам болох израильчуудыг албан ёсоор залж чиглүүлж эхэлсэн билээ. Израиль дахь ажил болон айлдвар нь Израилийн газар нутаг даяар амьдарч байсан Израилийн бүх ард түмэнд удирдамж өгсөн бөгөөд Ехова хүнд амьсгал үлээн оруулж, Өөрийн амийг өгөөд, тоос шорооноос бүтээгдсэн хүнийг бий болгож чадахаар үл барам, хүн төрөлхтнийг шатааж, харааж, Өөрийн таягийг ашиглан хүн төрөлхтнийг удирдаж чадна гэдгийг хүмүүст харуулсан юм. Иймээс, Ехова газар дээрх хүний амьдралыг залж чиглүүлж, хүн төрөлхтний дунд өдөр шөнийн цагийн дагуу үг хэлж, ажиллаж чадна гэдгийг ч бас тэд харжээ. Хүн Еховагийн атгасан шорооноос үүссэн, түүнчлэн хүнийг Ехова бүтээсэн гэдгийг Өөрийн бүтээлүүдэд мэдүүлэхийн тулд л Тэр энэ ажлыг хийсэн юм. Үүгээр ч зогсохгүй, бусад ард түмэн болон үндэстэн (үнэндээ тэд Израилиас тусгаар байгаагүй, харин Израилиас салбарласан ч мөн л Адам, Евагаас үүссэн байв) Израилиас Еховагийн сайн мэдээг хүлээн аваг гэсэндээ Тэрээр Өөрийн ажлыг Израильд анх хийсэн бөгөөд ингэснээр орчлон ертөнц дээрх бүх бүтээгдсэн зүйл Еховаг хүндэлж, дээдэлж чадах байлаа. Ехова Өөрийн ажлыг Израильд эхлэлгүй, харин оронд нь хүн төрөлхтнийг бүтээчхээд газар дээр дураар нь амьдруулсан бол, тэр тохиолдолд махан биеийнхээ уг чанараас болоод хүн (уг чанар гэдэг нь хүн харж чадахгүй зүйлээ хэзээ ч мэдэж чадахгүй гэсэн үг бөгөөд

Ехова хүн төрөлхтнийг бүтээснийг мэдэхгүй, Тэр яагаад үүнийг хийснийг бүр ч мэдэхгүй гэсэн үг юм), Ехова хүн төрөлхтнийг бүтээсэн гэдгийг, эсвэл Тэр бол бүх бүтээлийн Эзэн гэдгийг хэзээ ч мэдэхгүй байх байв. Хэрвээ Ехова хүнийг бүтээж, газар дээр тавьчхаад, дараа нь хэсэг хугацаанд удирдамж өгөхийн тулд хүн төрөлхтний дунд үлдэхийн оронд зүгээр л гар дахь тоосоо гөвөөд, явчихсан бол бүх хүн устан мөхөх байв; бүр Түүний бүтээсэн тэнгэр, газар, бүх зүйл, бүх хүн төрөлхтөн устан мөхөхийн сацуу Сатанаар гишгэлүүлэх байсан юм. Ийм маягаар, “Газар дээр буюу бүтээлүүдийнхээ дунд зогсох ариун газар Түүнд байх ёстой” гэсэн Еховагийн хүсэл сүйрэх байлаа. Иймээс хүн төрөлхтнийг бүтээснийхээ дараа Тэрээр амьдралыг нь залж чиглүүлэхийн тулд тэдний дунд үлдэж, тэдний дундаас тэдэнд хандан үг хэлж чаддаг байсан нь бүгд Түүний хүслийг гүйцэлдүүлж, Түүний төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө байсан юм. Израильд Түүний хийсэн ажил нь бүх зүйлийг бүтээхээсээ өмнө гаргасан төлөвлөгөөгөө биелүүлэх л зорилготой байсан, тиймээс эхлээд израильчуудын дунд ажилласан явдал болон бүх зүйлийг бүтээсэн нь хоорондоо зөрчилдөөгүй, харин хоёулаа Түүний удирдлага, Түүний ажил, Түүний алдрын төлөө, мөн хүн төрөлхтнийг бүтээснийх нь утга учрыг гүнзгийрүүлэхийн төлөө байсан билээ. Тэрээр Ноагаас хойш хоёр мянган жилийн турш газар дээрх хүн төрөлхтний амьдралыг залж чиглүүлсэн ба энэ хугацаандаа бүх зүйлийн Эзэн Еховаг хэрхэн хүндэлж, амьдралдаа биеэ хэрхэн авч явж, хэрхэн үргэлжлүүлэн амьдрах, хамгийн гол нь яаж Еховаг гэрчилж, Түүнд дуулгавартай байж, Түүнд хүндлэл үзүүлж, Давид болон түүний тахилчдын адилаар хөгжмөөрөө Еховаг магтан дуулахыг хүмүүст ойлгуулсан билээ.

Ехова хоёр мянган жил ажлаа хийхээс өмнө хүн юу ч мэддэггүй байсан бөгөөд бараг бүх хүн төрөлхтөн доройтолд орж, дэлхийг үерээр устгахаас өмнө садар самуун болон завхрал нь гүнзгийрч, зүрх сэтгэлд нь Ехова огт байхгүй, Түүний зам бүр ч байхгүй байсан. Тэд Еховагийн хийх гэж байгаа ажлыг огт ойлгоогүй; тэд эрүүл ухаангүй, тэр ч бүү хэл мэдлэггүй, амьсгалдаг машин шиг байсан бөгөөд хүн, Бурхан, дэлхий ертөнц, амь гэх мэтийг ер мэддэггүй байлаа. Газар дээр тэд могойтой адилаар олон уруу таталт явуулж, Еховад халдсан олон зүйл хэлсэн боловч мэдлэггүй байснаас нь болоод Ехова тэднийг гэсгээж, сахилгажуулаагүй юм. Үерийн дараа л, Ноаг 601 настай байхад Ехова Ноад албан ёсоор харагдаж, түүнийг болон гэр бүлийг нь залж чиглүүлж, үерээс амьд гарсан шувууд, амьтдыг Ноа болон түүний үр удмын хамтаар Хуулийн эрин үеийн төгсгөл хүртэл нийтдээ 2,500 жил удирджээ. Тэрээр Израильд ажилласан, өөрөөр хэлбэл, албан ёсоор нийт 2,000 жил ажилласан бөгөөд Израильд болон Израилийн гадна нэгэн зэрэг ажилласан хугацаа нь 500 жил байсан тул нийтдээ 2,500 жил болсон байна. Энэ хугацаанд Тэрээр, Еховад үйлчлэхийн тулд сүм барьж, тахилчийн өмсгөл өмсөх ёстой гэдгийг, мөн гутлаараа сүмийг бохирдуулж, сүмийн оройгоос гал бууж өөрсдийг нь шатаахаас зайлсхийхийн тулд сүм рүү үүрээр хөл нүцгэн орох ёстой гэдгийг израильчуудад зааварчилсан билээ. Тэд үүргээ биелүүлж, Еховагийн

зохицуулалтад захирагдсан юм. Тэгээд сүмд Еховад залбирдаг байсан ба Еховагаас илчлэл хүлээн авсныхаа дараа буюу Еховаг үг хэлсний дараа тэд хурсан олныг удирдан хөтөлж, Еховад—өөрсдийн Бурханд хүндлэл үзүүлэх ёстой гэдгийг тэдэнд зааж сургажээ. Мөн Ехова тэдэнд сүм болон тахилын ширээ барих ёстой гэж хэлсэн бөгөөд тэднийг хязгаарлаж, Еховаг хүндлэх зүрх сэтгэлтэй болгохын тулд Еховагийн тогтоосон цагт буюу Алгасал баяраар шинэ төрсөн тугал, хургыг бэлдэж, Еховад үйлчлэх тахил болгон тахилын ширээн дээр өргөх ёстой гэж хэлсэн юм. Тэд энэ хуулийг дуулгавартай дагах эсэх нь Еховад үнэнч зангийнх нь хэмжүүр болж байв. Ехова бас тэдэнд зориулан Өөрийн бүтээлийн долоо дахь өдрийг Амралтын өдөр болгон тогтоосон юм. Амралтын өдрийн маргаашийг Тэрээр нэг дэх өдөр буюу Еховаг магтах, Түүнд тахил өргөх, Түүнд зориулан хөгжим тоглох өдөр болгожээ. Энэ өдөр Ехова, тахилын ширээн дээрх тахилыг хүмүүст идүүлэхээр хуваахын тулд бүх тахилчийг дуудан цуглуулсан, ингэснээр тэд Еховагийн тахилын ширээн дээрх тахилыг эдэлж чадах байв. Тэгээд Ехова, тэд бол ерөөгдсөн, Түүнтэй хамт хуваалцдаг ба Түүний сонгосон хүмүүс мөн гэж хэлжээ (энэ нь израильчуудтай хийсэн Еховагийн гэрээ байлаа). Ийм учраас өнөөдрийг хүртэл Израилийн ард түмэн, Ехова бол зөвхөн тэдний Бурхан бөгөөд Харь үндэстнүүдийн Бурхан биш гэж хэлсээр байдаг.

Хуулийн эрин үед Ехова, өөрийг нь даган Египетээс гарсан израильчуудад дамжуулах олон тушаалыг Мосед буулгажээ. Эдгээр тушаалыг Ехова израильчуудад өгсөн бөгөөд египетчүүдтэй ямар ч хамаагүй байв; тэдгээр нь израильчуудыг хязгаарлах зорилготой байсан бөгөөд тэдэнд шаардлага тавихын тулд Тэрээр тушаалуудыг ашиглажээ. Тэд Амралтын өдрийг сахидаг эсэх, эцэг эхээ хүндэлдэг эсэх, хуурамч шүтээн шүтдэг эсэх гэх мэт нь нүгэлтэй юу, эсвэл зөв шударга уу гэдгийг нь шүүх зарчмууд байлаа. Тэдний дундаас зарим нь Еховагийн галд цохиулсан, зарим нь чулуу шидүүлж алуулсан, мөн зарим нь Еховагийн ерөөлийг хүртсэн бөгөөд эдгээр тушаалыг дуулгавартай дагасан эсэхийнх нь дагуу энэ нь шийдэгддэг байв. Амралтын өдрийг сахиагүй хүмүүсийг чулуугаар шидэж алдаг байжээ. Амралтын өдрийг сахиагүй тахилчид Еховагийн галд цохиулдаг байв. Эцэг эхдээ хүндлэл үзүүлдэггүй хүмүүсийг ч бас чулуу шидэж алдаг байлаа. Энэ бүгдийг Ехова сайшаадаг байв. Амьдралыг нь удирдах хугацаанд хүмүүс Түүний үгийг сонсож, дуулгавартай дагаж, Түүний эсрэг тэрслэхгүй байг гэсэндээ Ехова Өөрийн тушаалууд болон хуулийг тогтоожээ. Шинэ төрсөн хүн төрөлхтнийг хяналтдаа байлгаж, Өөрийнхөө хожмын ажлын суурийг илүү сайн тавихын тулд Тэр эдгээр хуулийг ашигласан юм. Иймээс Еховагийн хийсэн ажилд үндэслэн эхний эрин үеийг Хуулийн эрин үе гэж нэрлэжээ. Ехова олон айлдвар хэлж, ихээхэн ажил хийсэн боловч хүмүүсийг зөвхөн эерэгээр залж чиглүүлж байсан ба хэрхэн хүн байхыг, яаж амьдрахыг, Еховагийн замыг хэрхэн ойлгохыг энэ мэдлэггүй хүмүүст заажээ. Ихэнхдээ, Түүний хийсэн ажил нь хүмүүсээр Өөрийн замыг сахиулж, Өөрийн хуулийг дагуулахын төлөө байв. Уг ажил багахан завхарсан хүмүүс дээр хийгдсэн;

энэ нь тэдний зан чанарыг өөрчлөх, эсвэл амийн ахиц гаргах хэмжээнд хүртэл өргөжөөгүй. Тэрээр хүмүүсийг хязгаарлаж, хянахын тулд хуулийг хэрэглэхэд л анхаарч байв. Тухайн үеийн израильчуудын хувьд Ехова бол зүгээр л сүм дэх Бурхан, тэнгэр дэх Бурхан байлаа. Тэрээр үүлэн багана, галан багана байсан юм. Еховагийн тэднээс шаардсан бүхэн нь, өнөөдрийн хүмүүсийн Түүний хууль, тушаал гэж үздэг зүйлийг дагах явдал байв—үүнийг дүрэм ч гэж хэлж болно—учир нь Еховагийн хийсэн зүйл тэднийг өөрчлөхийн төлөө биш, харин хүнд байх учиртай илүү их зүйлийг тэдэнд өгч, тэдэнд Өөрийн амаар зааварчлахын төлөө байсан. Учир нь бүтээгдсэний дараа, хүний эзэмших ёстой зүйл хүнд огт байгаагүй юм. Иймээс Ехова хүмүүст, газар дээр амьдрахдаа эзэмших учиртай зүйлсийг нь өгч, Өөрийн удирдсан хүмүүсийг өвөг дээдэс болох Адам, Евагаас нь илүү гаргасан, учир нь Еховагийн тэдэнд өгсөн зүйл анх Адам, Ева хоёрт өгсөн зүйлээс нь илүү байлаа. Ямартай ч, Еховагийн Израильд хийсэн ажил нь зөвхөн хүн төрөлхтнийг залж чиглүүлэх, хүн төрөлхтөнд өөрсдийнх нь Бүтээгчийг таниулах л зорилготой байв. Тэр тэднийг байлдан дагуулаагүй, өөрчлөөгүй, харин ердөө л залж чиглүүлсэн юм. Энэ бол Хуулийн эрин үе дэх Еховагийн ажлын үр дүн билээ. Энэ бол Израилийн бүхий л газар нутаг дахь Түүний ажлын цаад шалтгаан, жинхэнэ түүх, мөн чанар бөгөөд хүн төрөлхтнийг Еховагийн гарын хяналтад байлгахын төлөөх зургаан мянган жилийн ажлынх нь эхлэл юм. Эндээс Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх илүү олон ажил төрөн гарсан юм.

ЗОЛИН АВРАЛЫН ЭРИН ҮЕИЙН АЖЛЫН ЦААД ҮНЭН ТҮҮХ

Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө болох зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нь эхний Хуулийн эрин үе; Нигүүлслийн эрин үе (энэ нь бас Золин авралын эрин үе юм); эцсийн өдрүүдийн Хаанчлалын эрин үе гэсэн гурван үе шат буюу гурван эрин үеэс бүрддэг. Энэ гурван эрин үе дэх Миний ажил өөр өөр эрин үеийн дагуу агуулгаараа ялгардаг боловч энэхүү ажил нь үе шат бүрд хүний хэрэгцээнд нийцдэг—илүү нарийн хэлбэл, энэ нь Сатаны эсрэг Миний явуулдаг дайнд Сатаны хэрэглэдэг арга мэхийн дагуу хийгддэг. Миний ажлын зорилго бол Сатаныг ялж, мэргэн ухаан, төгс хүчээ харуулж, мөн Сатаны бүх арга мэхийг илчилж, улмаар Сатаны эзэмшил дор амьдардаг бүхий л хүн төрөлхтнийг аврах явдал билээ. Энэ нь Өөрийн мэргэн ухаан, төгс хүчийг харуулж, мөн Сатаны тэвчишгүй муу муухайг илчлэхийн төлөө байдаг; цаашлаад сайн мууг ялгах, Би бол бүх зүйлийн Захирагч гэдгийг мэдэх, Сатан бол хүн төрөлхтний дайсан, адгийн муу, ёрын нэгэн гэдгийг тодорхой харах боломжийг бүтээгдсэн зүйлсэд олгож, мөн сайн ба муу, үнэн ба гажууд онол, ариун байдал ба бузар булай болон юу агуу, юу жигшүүртэй гэдгийн хоорондох ялгааг туйлын тодорхой ялган таних боломж

олгохын төлөө байдаг. Тийнхүү хүн төрөлхтнийг завхруулдаг нь Би биш, зөвхөн Бүтээгч болох Би л хүн төрөлхтнийг аварч, таашаан эдэлж чадах зүйлсийг нь хүмүүст хүртээж чадна хэмээн мэдлэггүй хүн төрөлхтөн Надад гэрчлэл хийж чаддаг болно; Би бол бүх зүйлийн Захирагч, Сатан бол Миний бүтээсэн зүйлсийн нэг төдий бөгөөд хожим нь Надаас урвасан юм гэдгийг тэд мэдэж авна. Миний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гурван үе шатанд хуваагддаг ба Би бүтээгдсэн зүйлсээр Өөртөө гэрчлэл хийлгэж, тэдэнд Өөрийн хүслийг ойлгуулж, Би бол үнэн гэдгийг мэдүүлэх үр дүнд хүрэхийн тулд ийнхүү ажилладаг. Тиймээс зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнийхөө эхний ажлын үеэр Би хуулийн ажил хийсэн нь Ехова хүмүүсийг залж чиглүүлсэн ажил байлаа. Хоёр дахь үе шат нь Иудейн тосгодод Нигүүлслийн эрин үеийн ажлыг эхлүүлсэн юм. Есүс Нигүүлслийн эрин үеийн бүх ажлыг төлөөлдөг; Тэрээр бие махбодтой болж, загалмайд цовдлогдсон бөгөөд бас Нигүүлслийн эрин үеийг эхлүүлсэн билээ. Тэрээр золин авралын ажлыг гүйцэлдүүлж, мөн Хуулийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийг эхлүүлэхийн тулд цовдлогдсон, иймээс Түүнийг “Өрлөг жанжин”, “Нүглийн тахил”, “Золин аврагч” гэж нэрлэжээ. Үүний үр дүнд, Есүсийн ажил болон Еховагийн ажил агуулгаараа ялгаатай байсан хэдий ч зарчим нь адилхан байсан юм. Ехова Хуулийн эрин үеийг эхлүүлэн, газар дээрх Бурханы ажилд зориулсан эхлэлийн цэг буюу суурийг тавьж, мөн хууль, тушаал гаргажээ. Энэ нь Түүний явуулсан ажлын хоёр хэсэг бөгөөд тэдгээр нь Хуулийн эрин үеийг төлөөлдөг. Нигүүлслийн эрин үед Есүсийн хийсэн ажил нь хууль гаргаагүй, харин тэдгээрийг гүйцэлдүүлж, улмаар Нигүүлслийн эрин үеийг авчирч, хоёр мянган жил үргэлжилсэн Хуулийн эрин үеийг дуусгасан юм. Тэрээр Нигүүлслийн эрин үеийг эхлүүлэхийн тулд ирсэн зам гаргагч байсан ч Түүний ажлын гол хэсэг золин аврал оршдог. Иймээс Түүний ажил ч бас шинэ эрин үеийг эхлүүлэх, мөн цовдлолоороо дамжуулан золин авралын ажлыг гүйцэлдүүлэх гэсэн хоёр хэсгээс бүрддэг бөгөөд дараа нь Тэр явж одсон. Тийнхүү Хуулийн эрин үе төгсөж, Нигүүлслийн эрин үе эхэлсэн билээ.

Есүсийн хийсэн ажил тухайн эрин үеийн хүний хэрэгцээний дагуу байв. Түүний ажил хүнийг золин аварч, нүглийг нь уучлахын төлөө байсан болохоор Түүний зан чанар бүхэлдээ даруу байдал, тэвчээр, хайр, чин сүсэг, хүлээцтэй байдал, өршөөл, энэрэн хайрлах сэтгэл байлаа. Тэрээр хүнд арвин их нигүүлсэл, ерөөл болон хүмүүсийн эдэлж чадах бүх зүйлийг авчирсан бөгөөд хүмүүсийн эдэлдэг бүхэн нь амар тайван, баяр хөөр ба Есүсийн хүлээцтэй байдал, хайр, өршөөл, энэрэл байсан юм. Тухайн үед хүмүүст учирсан эдэлж болох арвин их зүйл—зүрх сэтгэл доторх амар тайван, уужуу байдлын мэдрэмж, сүнсний тайтгарал, Аврагч Есүст түшиглэх байдал нь—бүгд тэдний амьдарч байсан эрин үетэй хамаатай байв. Нигүүлслийн эрин үед хүнийг Сатан аль хэдийн завхруулсан байлаа, иймээс бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлыг биелүүлэх нь арвин их нигүүлсэл, эцэс төгсгөлгүй хүлээцтэй байдал, тэвчээр шаардсан, үүнээс ч илүүтэйгээр, ажлын үр дүнд хүрэхийн тулд хүний нүглийг цайруулах хангалттай тахилыг шаардсан юм.

Нигүүлслийн эрин үед хүмүүсийн харсан зүйл нь ердөө хүний нүглийг цайруулах Миний тахил—Есүс байв. Бурхан өршөөнгүй, хүлээцтэй байж чадна гэдгийг л тэд мэддэг бөгөөд Есүсийн өршөөл, энэрлийг л хардаг. Энэ нь бүхэлдээ, тэд Нигүүлслийн эрин үед төрснөөс болсон билээ. Иймээс золин аврагдаж чадахаасаа өмнө тэд, Есүсийн хайрласан олон янзын нигүүлслийг эдлэх ёстой болжээ, ингэснээр л үр ашгийг нь хүртэх болно. Ийм маягаар, нигүүлсэл эдэлснээр тэд нүглээ уучлуулж, бас Есүсийн хайрласан тэсвэр, тэвчээрийг эдэлснээр золин аврууулах боломжтой болж чадах байлаа. Есүсийн тэсвэр, тэвчээрээр л дамжуулан тэд уучлал хүлээн авч, Есүсийн хайрласан элбэг дэлбэг нигүүлслийг эдлэх эрхийг олж авсан юм. Яг л Есүсийн хэлсэнчлэн: Би зөв шударга хүмүүсийг биш, харин нүгэлтнүүдийг золин аварч, нүгэлтнүүдэд нүглээ уучлуулах боломж олгохоор ирсэн. Махбод болох үедээ Есүс шүүлт, хараал, хүний халдахыг тэвчдэггүй зан чанарыг авчирсан бол хүн хэзээ ч золин аврагдах боломжгүй байсан бөгөөд үүрд нүгэлтэй хэвээр үлдэх байлаа. Ийм байсан бол зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө Хуулийн эрин үед зогсож, Хуулийн эрин үе зургаан мянган жилээр сунжрах байв. Хүний нүгэл улам их, улам хүнд болж, хүнийг бүтээсний ач холбогдол нь бүхэлдээ талаар болох байлаа. Хүмүүс хуулийн дор Еховад үйлчилж л чадах байсан боловч нүгэл нь анх бүтээгдсэн хүмүүсийнхээс давах байсан юм. Есүс хүн төрөлхтнийг улам их хайрлаж, хүний нүглийг уучилж, хүнд хангалттай өршөөл, өгөөмөр сэтгэл авчрах тусам тэд Есүсээр авруулж, Есүсийн асар их үнээр буцаан худалдаж авсан төөрсөн хурганууд гэж нэрлэгдэх улам их эрхтэй болсон билээ. Сатан ч бас энэ ажилд хөндлөнгөөс оролцож чадахгүй, учир нь нярай хүүхдээ энгэртээ тэвэрдэг энэрэлт эхийн адилаар Есүс дагалдагчдадаа хандаж байв. Тэрээр тэдэнд уурлаж, тэднийг жигшээгүй, харин тайтгарлаар дүүрэн байлаа; тэдний дунд Есүс хэзээ ч уурсан хилэгнээгүй, харин нүглийг нь тэвчсэн бөгөөд мунхаглал, мэдлэггүй байдлыг нь хараагүй дүр үзүүлж, “Бусдыг дал дахин долоон удаа уучил” хэмээн хэлэхэд хүрч, Түүний зүрх сэтгэл бусдын зүрх сэтгэлийг уяраасан. Ингэснээр л хүмүүс Түүний тэвчээрээр дамжуулан нүглээ уучлуулсан юм.

Есүс бие махбодтой болохдоо огт сэтгэл хөдлөлгүй байсан хэдий ч шавь нараа үргэлж тайтгаруулж, хангаж, тэдэнд тусалж, тэднийг дэмжсэн билээ. Тэр хэчнээн их ажил хийж, хэчнээн их зовлон туулсан ч бай, хүмүүст хэзээ ч хэтэрсэн шаардлага тавиагүй, харин тэдний нүгэлд үргэлж тэвчээртэй, хүлээцтэй хандсан, тийм болохоор Нигүүлслийн эрин үеийн хүмүүс Түүнийг “хайр татам Аврагч Есүс” хэмээн энхрийлэн нэрлэдэг байв. Тухайн үеийн хүмүүс буюу бүх хүний хувьд Есүст юу байгаа, Тэр юу болох нь өршөөл, энэрэл байлаа. Тэрээр хүмүүсийн гэм бурууг хэзээ ч санаагүй бөгөөд хэзээ ч гэм бурууд нь үндэслэн тэдэнд хандаж байсангүй. Өөр эрин үе байсан учраас хүмүүсийг цадталаа идэг гэсэндээ элбэг арвин хоол хайрладаг байлаа. Тэрээр бүх дагалдагчдаа нигүүлсэнгүй хандаж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, үхсэн хүнийг амилуулж байв. Хүмүүсийг Өөртөө итгүүлж, Түүний хийдэг бүхэн чин сэтгэлээр, үнэнчээр хийгддэг гэдгийг үзүүлэхийн

тулд Тэрээр илжирсэн цогцсыг амилуулахад ч хүрсэн бөгөөд үхсэн хүн ч Түүний гарт амилж болно гэдгийг харуулсан. Ийм маягаар Тэр чимээгүйхэн тэвчиж, тэдний дунд золин авралын ажлаа явуулсан билээ. Есүс, загалмайд цовдлогдохоосоо ч өмнө хүний нүглийг аль хэдийн Өөртөө үүрч, хүний төлөөх нүглийн тахил болсон. Тэрээр цовлогдохоосоо ч өмнө хүн төрөлхтнийг золин аврахын тулд загалмайн замыг нээсэн байв. Эцэст нь, загалмайд цовдлогдож, загалмайн төлөө Өөрийгөө золиосолж, Өөрийн бүх өршөөл, энэрэл, ариун байдлыг хүн төрөлхтөнд хайрлажээ. Тэрээр хүмүүст үргэлж хүлээцтэй хандаж, хэзээ ч хонзогноогүй бөгөөд тэдний нүглийг уучилж, гэмшихийг захиж, мөн тэсвэр, тэвчээр, хайр агуулж, Түүний мөрийг даган, загалмайн төлөө өөрсдийгөө золиослохыг тэдэнд зааж сургасан юм. Ах, эгч нарыг гэх Түүний хайр Мариаг гэх хайраас нь давсан. Түүний хийсэн ажил бүхэлдээ өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулахыг зарчмаа болгосон ба энэ бүхэн нь Түүний золин авралын төлөө байв. Тэр хаана ч очсон, Өөрийг нь дагаж байсан бүх хүнд нигүүлсэнгүй ханддаг байлаа. Тэрээр ядууг баян, суунги хүнийг алхдаг, сохрыг хардаг, дүлийг сонсдог болгож байв. Тэр ч бүү хэл, хамгийн дорд, ядуу хүмүүс, нүгэлтнүүдийг урьж, Өөртэйгээ нэг ширээнд суулгаж, тэднийг хэзээ ч гололгүй, харин үргэлж тэвчээртэй байж, “Хоньчин зуун хониноосоо нэгийг нь алдвал ерөн есөн хонио орхиод төөрсөн хонио хайхаар явна, тэгээд олох үедээ ихэд баярлан баясна” хэмээн хэлж ч байсан юм. Эм хонь хургаа хайрладгийн адилаар Тэр дагалдагчдаа хайрласан билээ. Тэд мунхаг, мэдлэггүй агаад Түүний нүдээр бол нүгэлтнүүд, түүнчлэн нийгмийн хамгийн доод давхаргын гишүүд байсан хэдий ч бусдын жигшдэг энэ нүгэлтнүүдийг Тэрээр нүдний цэцгий мэт авч үзжээ. Тэр тэднийг тоосон тул тахилын ширээн дээр өргөл болсон хурга мэтээр Өөрийн амийг тэдний төлөө өгсөн юм. Тэрээр зарц нь мэт тэдний дунд явж, Өөрийгөө тэдэнд ашиглуулж, нядлуулж, тэдэнд болзолгүйгээр захирагдсан. Дагалдагчдадаа Тэрээр хайр татам Аврагч Есүс байсан боловч өндөр индрээс хүмүүст зааж сургадаг фарисайчуудад өршөөл, энэрлийг бус, харин жигшил, зэвүүцэл харуулсан юм. Фарисайчуудын дунд Тэр их ажил хийгээгүй, хааяа нэг сургаж, зэмлэж байсан ба тэдний дунд золин авралын ажил хийгээгүй, мөн тэмдэг, гайхамшиг ч үзүүлээгүй. Өөрийн бүх өршөөл, энэрлийг дагалдагчдадаа хайрлаж, энэ нүгэлтнүүдийн төлөө бүр эцсээ хүртэл тэвчиж, загалмайд цовдлогдон, бүх хүн төрөлхтнийг бүрэн золин аврах хүртлээ доромжлол болгоныг амссан юм. Энэ нь Түүний бүхий л ажил байлаа.

Есүсийн золин авралгүйгээр хүн үүрд нүгэлд амьдарч, нүглийн үр, чөтгөрүүдийн үр сад болох байлаа. Тийнхүү үргэлжилсэн бол бүхий л дэлхий ертөнц Сатаны орогнодог орон буюу тэрний оршин суудаг газар болох байв. Гэхдээ золин авралын ажил нь хүнд өршөөл, энэрэл үзүүлэхийг шаарддаг; тийм арга замаар л хүн төрөлхтөн уучлал хүлээн авч, эцэстээ бүрэн төгс болгуулж, Бурханаар бүрэн авхуулах эрхийг олж авч чадах байсан юм. Ажлын энэ үе шатгүйгээр зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө өрнөж чадахгүй байх байлаа. Хэрвээ Есүс цовдлогдоогүй бол, хэрвээ Тэр ердөө л өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг зайлуулсан

бол хүмүүс нүглээ бүрэн уучлуулж чадахгүй байх байсан юм. Есүс газар дэлхий дээр ажлаа хийн өнгөрүүлсэн гурван жил хагасын хугацаандаа золин авралын ажлынхаа хагасыг л гүйцэлдүүлсэн; дараа нь загалмайд цовдлогдож, нүгэлт махан биеийн төрхтэй болж, ёрын муу нэгэнд өгөгдсөнөөр цовдлолын ажлыг гүйцэлдүүлж, хүн төрөлхтний хувь заяаг захирах болжээ. Сатаны гарт хүргэгдсэнийхээ дараа л Тэр хүн төрөлхтнийг золин аварсан юм. Гучин гурван жил хагасын хугацаанд Тэрээр газар дээр зовж, дооглуулж, гутгүүлж, хаягдаж, тэр ч бүү хэл толгой хоргодох газаргүй, амрах газаргүй болоход хүрсэн бөгөөд дараа нь цовдлогдож, Түүний бүхий л оршихуй—ариун агаад гэм зэмгүй бие—загалмайд хадагдсан. Тэрээр бүх төрлийн зовлонг туулсан юм. Эрх мэдэлтэй хүмүүс Түүнийг тохуурхаж, ташуурдаж, цэргүүд бүр нүүр лүү нь нулимсан; гэсэн ч Тэр чимээгүй байж, эцсээ хүртэл тэвчин, үхэн үхтэлээ нөхцөл болзолгүй захирагдаж, улмаар бүх хүн төрөлхтнийг золин аварсан билээ. Тэр үед л Тэрээр амрах боломжтой болсон. Есүсийн хийсэн ажил Нигүүлслийн эрин үеийг л төлөөлдөг; энэ нь Хуулийн эрин үеийг төлөөлдөггүй, эцсийн өдрүүдийн ажлыг ч орлодоггүй. Энэ бол хүн төрөлхтний туулсан хоёр дахь эрин үе болох Нигүүлслийн эрин үе—Золин авралын эрин үе дэх Есүсийн ажлын мөн чанар билээ.

ХӨГШИН ЗАЛУУ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН ҮГ

Би газар дээр асар их хэмжээний ажил хийж, хүн төрөлхтний дунд маш олон жилийн турш алхсан атал хүмүүс Миний дүр, Миний зан чанарын талаар мэдлэгтэй байх нь ховор бөгөөд Миний хийдэг ажлыг цөөхөн хүн л нэгд нэггүй тайлбарлаж чадна. Хүмүүст маш олон зүйл дутагддаг, мөн Миний хийдэг зүйлийн талаарх ойлголт үргэлж дутагддаг бөгөөд Би тэднийг өөр нөхцөл байдалд оруулаад, дараа нь ямар ч анхаарал хандуулахгүй байх вий гэдгээс гүнээ айдаг мэт зүрх сэтгэл нь үргэлж сэрэмжтэй байдаг. Тиймээс Надад хандах хүмүүсийн хандлага үргэлж бүлээн байж, асар их болгоомжлолтой хосолж байдаг. Учир нь хүмүүс Миний хийдэг ажлыг ойлгохгүйгээр өнөөг хүрсэн бөгөөд ялангуяа тэдэнд хэлдэг үгээс минь болж төөрөлддөг. Тэд Миний үгийг гартаа бариад, тэдгээрт тууштай итгэхээр шийдэх ёстой юу, эсвэл шийдэмгий бус байж, тэдгээрийг мартахаар сонгох ёстой юу гэдгээ мэддэггүй. Тэд үүнийг хэрэгжүүлэх ёстой юу, эсвэл харзнах ёстой юу гэдгээ мэддэггүй, бүх зүйлийг хаяж, зоригтойгоор дагах ёстой юу, эсвэл урьдынх шигээ дэлхий ертөнцөд “нөхөрсөг” хандсаар байх ёстой юу гэдгээ мэддэггүй. Хүмүүсийн дотоод ертөнц маш адармаатай бөгөөд тэд маш зальтай. Хүмүүс Миний үгийг тодорхой, бүрэн дүүрэн харж чаддаггүй учраас олонхынх нь хувьд тэдгээрийг хэрэгжүүлэхэд бэрх байдаг ба Миний өмнө зүрх сэтгэлээ тавихад хэцүү байдаг. Би та нарын бэрхшээлийг гүнээ ойлгодог. Махан биед амьдарч байхад олон сул талаас зайлсхийх аргагүй бөгөөд олон бодит хүчин зүйл та нарт бэрхшээл

учруулдаг. Та нар гэр бүлээ тэжээж, шаргуу ажиллан өдөр хоногоо өнгөрүүлдэг ба хүндрэл бэрхшээл дунд сар жилүүд урсан өнгөрдөг. Махан биед амьдрахад олон бэрхшээл байдаг—Би үүнийг үгүйсгэдэггүй бөгөөд мэдээж та нарт тавих Миний шаардлага бэрхшээлд чинь нийцсэн байдаг. Миний хийдэг ажлын шаардлага бүгд та нарын бодит биеийн хэмжээнд үндэслэдэг. Урьд нь хүмүүс ажиллаж байхдаа хэрээс хэтэрсэн элементүүдтэй холилдсон шаардлагыг та нарт тавьсан байж магадгүй, гэхдээ Өөрийн хэлж, хийж байгаа зүйлээрээ Би та нарт хэзээ ч хэрээс хэтэрсэн шаардлага тавьж байгаагүй гэдгийг та нар мэдэх ёстой. Бүх шаардлага хүмүүсийн уг чанар, махан бие болон тэдэнд хэрэгтэй зүйлд үндэслэдэг. Би хүмүүст байдаг тодорхой нэг ухаалаг сэтгэлгээ болон хүн төрөлхтний төрөлх уг чанарыг эсэргүүцдэггүй гэдгийг та нар мэдэх ёстой ба Би та нарт тун тодорхой хэлж болно. Миний тогтоосон шаардлагын стандарт үнэндээ юу болохыг хүмүүс ойлгодоггүй, мөн Миний үгийн анхдагч утга учрыг ч ойлгодоггүй учраас л хүмүүс одоог хүртэл Миний үгийн талаар эргэлзсээр ирсэн бөгөөд хүмүүсийн хагасаас ч цөөхөн нь л Миний үгэнд итгэдэг. Үлдсэн нь үл итгэгчид бөгөөд бүр ч олон нь “үлгэр ярихыг” минь сонсох дуртай хүмүүс юм. Түүнчлэн, үзвэр үздэг хүн олон бий. Би та нарт анхааруулж байна: Миний үгийн олонх нь Надад итгэдэг хүмүүст ил болсон бөгөөд хаанчлалын сайхан дүр зургийг таашаадаг боловч хаалганых нь гадна талд түгжигдсэн хүмүүсийг Би аль хэдийн таягдан хаясан. Та нар ердөө Надаар жигшигдэн, гологдсон үрийн сүүл биш гэж үү? Та нар Миний явахыг хараад, дараа нь эргэн ирэхийг минь баяр хөөртэйгээр угтаж яаж чадах юм бэ? Ниневегийн ард түмэн Еховагийн ууртай үгийг сонссоныхоо дараа таар болон үнсэн дотор нэн даруй гэмшсэн гэдгийг Би та нарт хэлье. Тэд Түүний үгэнд итгэсэн учраас айдас хүйдсээр дүүрэн байсан бөгөөд таар болон үнсэн дунд гэмшсэн юм. Өнөөдрийн хүмүүсийн тухайд бол, та нар ч бас Миний үгэнд итгэдэг, өнөөдөр та нарын дунд Ехова дахин нэгэнтээ ирсэн гэдэгт бүр ч их итгэдэг хэдий ч олон мянган жилийн өмнө Иудейд төрсөн Есүс одоо та нарын дунд буун ирснийг ажиглаж байгаа мэт хандлага чинь ердөө хүндэтгэлгүй байдаг. Та нарын зүрх сэтгэл дотор оршдог ов мэхтэй байдлыг Би гүнээ ойлгодог; та нарын ихэнх нь сониуч зангаасаа болж Намайг дагадаг бөгөөд хоосон байдлынхаа улмаас Намайг эрж хайж эхэлсэн. Амар амгалан, аз жаргалтай амьдралын төлөөх гурав дахь хүсэл чинь сүйрэх үед сониуч зан чинь ч бас сарнидаг. Та бүхний зүрх сэтгэлд оршдог ов мэхтэй байдал үг болон үйл хэргээр чинь дамжуулан илчлэгддэг. Шулуухан хэлэхэд, та нар зүгээр л Миний талаар сониучирхдаг ч Надаас айдаггүй; та нар ам хэлээ анхаардаггүй, өөрсдийн зан авирыг бүр ч хазаарладаггүй. Тэгвэл үнэндээ та нарт ямар итгэл байна вэ? Энэ нь жинхэнэ үү? Та нар санаа зовнилоо сарниулж, уйтгар гунигаа нимгэлж, өөрсдийн амьдрал дахь үлдсэн хоосон зайгаа дүүргэхийн тулд л Миний үгийг ашигладаг. Та нарын дундаас хэн Миний үгийг хэрэгжүүлсэн бэ? Хэнд жинхэнэ итгэл байна вэ? Та нар Бурхан бол хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнийг хардаг Бурхан гэж хашхирсаар байдаг ч зүрх сэтгэлдээ дууддаг Бурхан чинь яаж Надтай нийцэлтэй байх юм бэ?

Нэгэнт та нар ингэж хашхирч байгаа юм чинь яагаад тийм маягаар үйлддэг юм бэ? Та нар Миний ачийг энэ хайраар хариулахыг хүсэж байгаа юм гэж үү? Та нар ам хэлээрээ багагүй хэмжээгээр зориулдаг боловч та нарын тахил, та нарын сайн үйл хэрэг хаана байна вэ? Үг чинь Миний чихэнд хүрээгүй сэн бол Би яаж та нарыг ийм их үзэн ядаж чадах юм бэ? Хэрвээ та нар Надад үнэхээр итгэдэг байсан бол яаж ийм гаслантай байдалд орж чадах юм бэ? Та нар Үхэгсдийн орны шүүх хуралд орж байгаа юм шиг нүүрэн дээрээ цөхөрсөн байдалтай байдаг. Та нарт өчүүхэн ч эрч хүч байхгүй бөгөөд өөрсдийн дотоод дуу хоолойны талаар сулхан ярьдаг; та нар бүр гомдол, хараалаар дүүрэн байдаг. Та нар Миний хийдэг зүйлд итгэх итгэлээ аль эрт алдаж, анхны итгэл чинь ч үгүй болсон, иймээс та нар яаж эцсийг нь хүртэл дагаж чадах юм бэ? Ийм болохоор та нар яаж аврагдаж чадах юм бэ?

Хэдийгээр Миний ажил та нарт маш тустай боловч Миний үг та нарт үргэлж үр нөлөөгүй байж, хий дэмий болдог. Надаар төгс болгуулах бай олоход хэцүү бөгөөд өнөөдөр Би та нарт найдах найдвараа бараг алдсан. Би та нарын дундаас хэдэн жилийн турш хайсан боловч Миний итгэлийг хүлээж чадах хүн олоход бэрх. Та нар дээр үргэлжлүүлэн ажиллах итгэл болон та нарыг үргэлжлүүлэн хайрлах хайр Надад байхгүй мэт санагддаг. Учир нь Би аль эртнээс та нарын туйлын өчүүхэн, өрөвдөлтэй “амжилтуудыг” зэвүүцэх болсон; Би та нарын дунд хэзээ ч үг хэлээгүй мэт, мөн та нар дээр хэзээ ч ажиллаагүй мэт санагддаг. Та нарын амжилт маш огиудас хүрэм. Та нар үргэлж өөрсдийгөө сүйрүүлж, шившиглэдэг ба бараг ямар ч үнэ цэнгүй. Би та нараас хүний төрхийг олж бараг чаддаггүй, хүний ул мөрийг үнэрлэж ч чаддаггүй. Та нарын шинэхэн үнэр хаана байна вэ? Олон жилийн турш төлсөн төлөөс чинь хаана байна, мөн үр дүн хаана байна вэ? Та нар хэзээ ч, юу ч олоогүй юу? Миний ажилд одоо шинэ эхлэл, шинэ гараа байгаа. Би агуу их төлөвлөгөө биелүүлэх гэж байгаа бөгөөд бүр ч илүү том ажил гүйцэтгэхийг хүсдэг атал та нар урьдынх шигээ шавар шавхайд хөрвөөн, өнгөрсөн үеийн бохир заваан усанд амьдарсаар байгаа ба үнэн хэрэгтээ өөрсдийн анхдагч хүндрэлээсээ салж чадаагүй. Тиймээс та нар Миний үгээс мөн л юу ч олж авсангүй. Та нар шавар шавхай, бохир заваан устай анхны газраасаа салаагүй бөгөөд Миний үгийг л мэддэг боловч үнэндээ Миний үгийн эрх чөлөөний ертөнцөд ороогүй тул Миний үг хэзээ ч та нарт дэлгэгдээгүй; тэдгээр нь олон мянган жилийн туршид битүүмжлэгдсээр ирсэн зөгнөлийн ном шиг байдаг. Би амьдралд чинь та нарт харагддаг боловч та нар үүнийг үргэлж мэддэггүй. Та нар бүр Намайг ч таньдаггүй. Миний хэлдэг үгийн бараг хагас нь та нарыг шүүх шүүлт байдаг бөгөөд хүрэх ёстой үр дүнгийнхээ хагаст л хүрч, та нарын дотор гүн айдас төрүүлдэг. Үлдсэн хагас нь амьдралын тухай, биеэ хэрхэн авч явах тухай та нарт зааж сургах үгээс бүрддэг. Гэхдээ та нарын тухайд бол, тэдгээр нь бүр оршин байдаггүй юм шиг, эсвэл та нар хүүхдүүдийн үг буюу үргэлж нууцхан инээмсэглэдэг ч хэзээ ч биелүүлдэггүй үгээ сонсож байгаа мэт байдаг. Та нар эдгээр зүйлийн талаар хэзээ ч санаа тавьж байгаагүй; та нар үндсэндээ сониуч зангаасаа болоод Миний үйлдлүүдийг үргэлж

ажигласаар ирснийхээ үр дүнд одоо харанхуйд унаж, гэрлийг харж чаддаггүй тул харанхуйд хөөрхийлөлтэйгээр уйлж байдаг. Миний хүсдэг зүйл бол та нарын дуулгавартай байдал буюу ямар ч болзолгүй дуулгавартай байдал бөгөөд түүнээс ч илүүтэйгээр Миний хэлж байгаа бүхний талаар бүрэн итгэлтэй байхыг Би та нараас шаарддаг. Та нар үл ойшоосон хандлага баримтлах ёсгүй бөгөөд ялангуяа Миний хэлдэг зүйлийг шилж сонгон авч үзэх ёсгүй, мөн сурсан дадсанаараа Миний үг болон Миний ажилд хайхрамжгүй хандах ч ёсгүй. Миний ажил та нарын дунд хийгддэг бөгөөд Би та нарт асар их үгээ хайрласан боловч хэрвээ та нар Надад ийм маягаар хандах юм бол та нарын олж аваагүй, эсвэл хэрэгжүүлээгүй зүйлсийг Би Харь үндэстний гэр бүлүүдэд өгөхөөс өөр аргагүй. Бүтээгдсэн бүх зүйлийн дундаас хэн Миний гарт байдаггүй вэ? Та нарын дундаас олонх нь “боловсорч гүйцсэн ахимаг насандаа” байгаа бөгөөд Надад байгаа ийм ажлыг хүлээн авах эрч хүчгүй байдаг. Та нар Ханхао шувуу[a] шиг арай ядан амь зуудаг ба Миний үгэнд хэзээ ч нухацтай хандаагүй. Залуучууд туйлын нэрэлхүү, хэт эрхэлсэн бөгөөд Миний ажлыг бүр ч бага анхаардаг. Тэдэнд Миний цайллагын амттануудыг амсах сонирхол байдаггүй; тэд алс хол явахаар торноосоо ниссэн бяцхан шувуу шиг байдаг. Ийм төрлийн хөгшин, залуу хүмүүс яаж Надад хэрэгтэй байх юм бэ? Ахимаг насны хүмүүс булшиндаа орох хүртлээ Миний үгийг тэтгэвэр болгон ашиглахад бэлэн байдаг, ингэснээр нас барсных нь дараа тэдний сүнс тэнгэр лүү явж чадна; тэдний хувьд тэр нь л хангалттай. Одоо энэ хөгшчүүл үргэлж “агуу тэмүүлэл”, “гуйвшгүй итгэл” өвөрлөдөг. Хэдийгээр тэд Миний ажлын төлөө асар тэвчээртэй байж, шулуун шударга, нугаршгүй, мөн хэнд ч, эсвэл юунд ч чангаагдаж, ялагдахаас татгалздаг хөгшин хүний чанарыг эзэмшиж, үнэхээр халдашгүй хэрэм шиг байдаг ч—энэ хүмүүсийн итгэл нь үхдэлийн мухар сүсэгтэй үнэрээр дүүрэн байдаггүй гэж үү? Тэдний зам хаана байна вэ? Тэдний хувьд зам нь хэтэрхий урт, хэтэрхий алслагдмал биш гэж үү? Тэд Миний хүслийг яаж мэдэж чадах юм бэ? Тэдний итгэл үнэмшлийг магтууштай ч гэсэн эдгээр “ахмадын” хэчнээн нь төөрөлдөж будилсан байдлаар дагалгүй, харин амийг эрэлхийлж байгаа вэ? Хэчнээн нь Миний ажлын бодит ач холбогдлыг үнэхээр ойлгодог вэ? Хэнийх нь зорилго, өнөөдрийн энэ дэлхийд Намайг дагаснаараа ойрын ирээдүйд Үхэгсдийн орон руу буухгүйгээр, харин Надаар өөр ертөнц рүү хүргүүлэхийн төлөө байдаггүй вэ? Та нарын хүрэх газар тийм энгийн асуудал гэж та нар бодож байна уу? Хэдийгээр залуу хүмүүс та нар бүгд залуу арслан шиг байдаг боловч зүрх сэтгэлд чинь үнэн зам байх нь ховорхон. Залуу нас чинь та нарт Миний ажлаас илүү ихийг хүртэх эрх олгодоггүй; эсрэгээрээ та нар үргэлж Миний зэвүүцлийг өдөөдөг. Хэдий

[a] Ханхао шувууны түүх нь шоргоолж, царцаа хоёрын тухай Эзопын ёгт үлгэртэй тун адилхан. Ханхао шувуу өөрийн хөрш, алаг шаазгайн олон удаагийн анхааруулгыг үл харгалзан, цаг агаар дулаахан байх зуур үүрээ барихын оронд унтахыг илүүд үздэг. Өвөл болоход уг шувуу хөлдөж үхдэг.

та нар залуу ч гэсэн та нарт эрч хүч, эсвэл хүсэл эрмэлзэл дутагддаг, та нар ирээдүйнхээ талаар үргэлж булзамтгай байдаг; та нар хайхрамжгүй агаад бодлогоширсон мэт байдаг. Залуу хүмүүст байх учиртай эрч хүч, туйлын хүслэн болон үзэл бодлыг та нараас яавч олж чадахгүй гэж хэлж болно; иймэрхүү залуу хүмүүс та нар байр суурьгүй, зөв буруу, сайн муу, сайхан муухайг ялгах ямар ч чадваргүй байдаг. Та нараас ямар ч шинэхэн хэсэг олох боломжгүй. Та нар бараг бүхэлдээ хуучинсаг бөгөөд ийм төрлийн залуу хүмүүс та нар ч бас олныг дагаж, бодлогогүй байж сурсан. Та нар зөвийг буруугаас илт салгаж хэзээ ч чаддаггүй, үнэн худлыг ялгаж чаддаггүй, өндөр ур чадварын төлөө хэзээ ч чармайдаггүй, мөн юу зөв, юу буруу, юу үнэн, юу хуурамч болохыг ч хэлж чаддаггүй. Та нарт хөгшин хүмүүст байдгаас ч их, илүү ноцтой шашны таагүй үнэр байдаг. Та нар бүр биеэ тоосон, бодлогогүй, өрсөлдөөнтэй бөгөөд түрэмгийлэлд дурладаг чинь маш их—ийм төрлийн залуу хүн яаж үнэнийг эзэмшиж чадах юм бэ? Үзэл бодлоо хадгалж чаддаггүй хүн яаж гэрчлэлд зогсож чадах юм бэ? Зөв, бурууг ялгах чадваргүй хүнийг яаж залуу хүн гэж нэрлэж болох юм бэ? Залуу хүний эрч хүч, цог золбоо, шинэлэг, тайван, туйлбартай зан байхгүй хүнийг яаж Миний дагалдагч гэж нэрлэж болох юм бэ? Ямар ч үнэнгүй, шударга ёсны мэдрэмжгүй мөртөө тоглож, тэмцэлдэх дуртай хүн яаж Миний гэрчлэгч байх эрхтэй байх юм бэ? Хууран мэхлэлт болон бусдыг ялгаварлах үзлээр дүүрэн нүд бол залуу хүмүүст байх ёстой зүйл биш бөгөөд залуу хүмүүс хор хөнөөлтэй, олиггүй үйл үйлдэх ёсгүй. Тэд туйлын хүслэн, тэмүүлэл болон өөрсдийгөө сайжруулах оргилуун хүсэлгүй байх ёсгүй; тэд өөрсдийн хэтийн ирээдүйн талаар зориг алдрах ёсгүй, мөн амьдралд итгэл найдвараа алдаж, ирээдүйд итгэх итгэлээ алдах ч ёсгүй; тэд бүхий л амьдралаа Миний төлөө зарлагадах хүслээ биелүүлэхийн тулд одоо сонгосон үнэний замаар үргэлжлүүлэх тэвчээртэй байх ёстой. Тэд үнэнгүйгээр байх ёсгүй, хуурамч дүр, шударга бус байдлыг ч өвөрлөх ёсгүй—харин зүй зохистой үзэл бодолдоо бат зогсох учиртай. Тэд зүгээр л урсгал даган хөвөх ёсгүй, харин шударга ёс болон үнэний төлөө золиос гаргаж, тэмцэж зүрхлэх цог золбоотой байх ёстой. Залуу хүмүүс харанхуйн хүчний дарангуйлалд автахгүй байж, оршин тогтнолынхоо ач холбогдлыг өөрчлөх зориг зүрхтэй байх ёстой. Залуу хүмүүс гай зовлонд буулт хийх ёсгүй, харин ах эгч нараа уучлах сэтгэлтэйгээр илэн далангүй, эрс шулуун байх ёстой. Мэдээж эдгээр нь хүн бүрд тавих Миний шаардлага, мөн хүн болгонд өгөх Миний зөвлөгөө юм. Үүнээс ч илүүтэйгээр энэ нь бүх залуу хүнд хэлэх тайвшруулсан үг минь юм. Та нар Миний үгийн дагуу хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа залуу хүмүүс асуудлыг ялган таних, шударга ёс болон үнэнийг эрж хайх шийдвэргүй байж болохгүй. Та нар сайн сайхан бүх зүйлийг эрэлхийлэх ёстой бөгөөд бүх эерэг зүйлийн бодит байдлыг олж авах ёстой. Та нар амьдралдаа хариуцлагатай байх ёстой ба үүнийг хөнгөхнөөр авч үзэх ёсгүй. Хүмүүс газар дэлхийд ирээд Надтай учрах нь ховорхон, үнэнийг эрж хайж, олж авах боломжтой байх нь ч бас хомсхон. Яагаад та нар энэ сайхан цаг хугацааг энэ амьдралд

эрэлхийлэх зөв зам хэмээн эрхэмлэдэггүй юм бэ? Яагаад та нар үнэн болон шударга ёсыг үргэлж үл тоомсорлодог юм бэ? Хүмүүсээр тоглодог тэрхүү шударга бус байдал болон бузар заваан байдлын төлөө яагаад та нар өөрсдийгөө үргэлж гишгэлэн, сүйтгэж байдаг юм бэ? Яагаад та нар, шударга бусчуудын хийдэг зүйлд оролцдог тэр хөгшин хүмүүс шиг авирладаг юм бэ? Яагаад та нар хуучин зүйлсийн хуучин арга замыг дуурайдаг юм бэ? Та нарын амьдрал шударга ёс, үнэн, ариун байдлаар дүүрэн байх ёстой; ийм залуу насанд амьдрал чинь тун доройтмол байж, чамайг Үхэгсдийн орон руу хөтлөх ёсгүй. Энэ нь асар золгүй байна гэдгийг та нар мэдрэхгүй байна гэж үү? Энэ нь асар шударга бус байна гэдгийг мэдрэхгүй байна гэж үү?

Та бүхэн туйлын төгс ажил хийж, үүнийгээ Миний тахилын ширээн дээр өргөөд, Надад өгөх өөрсдийн эцсийн, цор ганц тахил болгох ёстой. Та нар бүгд үзэл бодолдоо бат зогсож, сэвэлзүүр салхи үлээх болгонд тэнгэрийн үүл мэт хөвөхгүй байх ёстой. Та нар амьдралынхаа хагаст шаргуу ажилладаг, тиймээс яагаад өөрсдийн хүрэх ёстой газраа эрж хайхгүй гэж? Та нар бүхий л амьдралынхаа хагаст хөдөлмөрлөдөг ч гахай, нохой мэт эцэг эх чинь та нарын оршин тогтнолын үнэн болон ач холбогдлыг булш руугаа чирдэг. Энэ нь та нарын хувьд асар шударга бус явдал гэж чамд санагдахгүй байна гэж үү? Ийм маягаар амьдрах нь үнэхээр утга учиргүй гэж чамд санагдахгүй байна гэж үү? Ийм маягаар үнэн болон зөв замыг эрж хайх нь асуудал үүсгэж таарах болохоор хөршүүд тайван бус, бүхий л гэр бүл аз жаргалгүй байх бөгөөд энэ нь хөнөөлт гай гамшиг руу хөтөлнө. Чи ийм маягаар амьдардаг бол энэ нь хамгийн утга учиргүй амьдрал биш гэж үү? Хэний амьдрал чинийхээс илүү золтой байж чадах юм бэ, бас хэний амьдрал чинийхээс илүү инээдтэй байж чадах юм бэ? Чи Миний баяр хөөрийг олж авахын төлөө, чамайг тайвшруулах үгийг олж авахын төлөө Намайг эрж хайдаггүй гэж үү? Гэхдээ нэг насны амьдралынхаа хагаст ийш тийш гүйснийхээ дараа чи, уур хилэнгээр дүүрч, чамайг тоохгүй, эсвэл чамайг магтахгүй байх хүртэл Намайг өдөөдөг—тэгэхээр бүхий л амьдрал чинь хий дэмий өнгөрсөн гэсэн үг бус уу? Тэгвэл чи ариутгалын ертөнцөөс чөлөөлөгдсөн, эрин үеүдийн туршид байсан ариун хүмүүсийн сүнсийг харахаар явах нүүртэй байж яаж чадах юм бэ? Чи Надад хайхрамжгүй ханддаг бөгөөд эцэст нь хөнөөлт гай гамшиг учруулдаг—энэ боломжийг ашиглаад өргөн уудам далайгаар баяр хөөртэй аялал хийж, дараа нь Миний “томилолтыг” дуулгавартай дагасан чинь дээр. Өнөөдөр ийм хайхрамжгүй байдаг мөртөө холдон явах хүсэлгүй байдаг чи эцэстээ Миний үүсгэсэн давлагаанд автаж, залгиулах болно гэдгийг Би та нарт аль хэдийн хэлсэн. Та нар өөрсдийгөө хамгаалж үнэхээр чадах уу? Эрэл хайгуулын чинь одоогийн арга барил чамайг гарцаагүй төгс болгуулна гэдэгт чи үнэхээр итгэлтэй байна уу? Зүрх сэтгэл чинь маш хатуу биш гэж үү? Ийм төрлийн дагах явдал, ийм төрлийн эрэл хайгуул, ийм төрлийн амьдрал, ийм төрлийн ёс жудаг—яаж Миний магтаалыг хүртэж чадах юм бэ?

БҮХ ХҮН ТӨРӨЛХТӨН ӨНӨӨГ ХҮРТЭЛ ХЭРХЭН ХӨГЖСӨНИЙГ ЧИ МЭДЭХ ЁСТОЙ

Зургаан мянга гаруй жил хийгдсэн бүхий л ажил эрин үе өнгөрөхийн хэрээр аажмаар өөрчлөгджээ. Энэхүү ажлын өөрчлөлт нь дэлхий ертөнцийн ерөнхий нөхцөл байдал болон нийт хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлагад үндэслэсээр ирсэн юм; тийнхүү удирдлагын ажил гагцхүү аажмаар өөрчлөгдсөн билээ. Үүнийг бүтээлийн эхэн үед төлөвлөөгүй. Дэлхий ертөнц бүтээгдэхээс өмнө, эсвэл бүтээгдсэний дараахан Ехова, ажлын эхний үе шат нь хуулийн үе шат, ажлын хоёр дахь үе шат нь нигүүлслийн үе шат, эсвэл ажлын гурав дахь үе шат нь байлдан дагуулалтын үе шат байна, үүнийг эхлээд Моабын үр удмын зарим хүнээс эхлүүлж, үүгээр дамжуулан бүх орчлон ертөнцийг байлдан дагуулна гэж төлөвлөөгүй. Дэлхийг бүтээснийхээ дараа Тэр эдгээр үгийг огт хэлээгүй, Моабын дараа ч ингэж хэлээгүй; үнэндээ Лотоос өмнө ч Тэр ингэж огт айлдаагүй юм. Бурханы бүх ажил аяндаа хийгддэг. Яг ийм маягаар л Түүний бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө хөгжсөн; дэлхий ертөнцийг бүтээхээсээ өмнө Тэрээр “Хүн Төрөлхтний Хөгжлийн Хураангуй Хүснэгт” гэх мэтийн төлөвлөгөө зохиогоогүй. Өөрийнхөө ажлаар Бурхан Өөрийнхөө юу болохыг шууд илэрхийлдэг; Тэр төлөвлөгөө зохиох гэж тархиа гашилгадаггүй. Мэдээж, нэлээд олон эш үзүүлэгч асар олон зөгнөл хэлсэн, гэхдээ Бурханы ажил үргэлж нарийн нягт төлөвлөгдсөөр ирсэн гэж хэлж мөн л болохгүй; тэдгээр зөгнөл нь тухайн үеийн Бурханы ажлын дагуу хэлэгдсэн. Түүний хийдэг бүх ажил нь хамгийн бодитой ажил юм. Тэрээр эрин үе бүрийн хөгжилд нийцүүлэн, аливаа зүйлсийн өөрчлөлтөд үндэслэн ажлаа хэрэгжүүлдэг. Түүний хувьд, ажлаа хэрэгжүүлэх гэдэг нь өвчинд тохирсон эм бичихтэй адил; Тэрээр ажлаа хийх зуураа ажигладаг ба ажиглалтынхаа дагуу ажлаа үргэлжлүүлдэг. Ажлынхаа үе шат болгонд Бурхан Өөрийн асар их мэргэн ухаан, чадварыг илэрхийлэх чадвартай; Тэрээр тодорхой нэг эрин үеийн ажлын дагуу Өөрийн үлэмж арвин мэргэн ухаан, эрх мэдлийг илчилдэг ба тухайн эрин үеийн турш Өөрийн буцаан авчирсан бүх хүнд бүхий л зан чанараа харуулдаг. Тэрээр эрин үе болгонд хийгдэх хэрэгтэй ажлын дагуу хүмүүсийн хэрэгцээг хангаж, хийх ёстой ажлаа хийдэг. Мөн Сатаны завхруулсан түвшинд үндэслэн хэрэгтэй зүйлээр нь хүмүүсийг хангадаг. Ехова анх Адам, Еваг бүтээх үедээ газар дээр Бурханыг харуулах боломжийг тэдэнд олгосон ба ингэснээр тэд бүтээлийн дунд Бурханд гэрчлэл хийж чадах байв. Гэвч Ева могойд уруу татагдсаныхаа дараа нүгэл үйлдэж, Адам ч мөн адил зүйл хийсэн; тэд цэцэрлэг дэх сайн, мууг мэдүүлэгч модны жимсийг хоёулаа идсэн. Тиймээс, Ехова тэдэн дээр нэмэлт ажил явуулах хэрэгтэй болсон юм. Тэдний нүцгэн байгааг хараад Тэр амьтны арьсаар хийсэн хувцсаар биеийг нь халхалсан. Дараа нь Тэрээр Адамд: “Чи эхнэрийнхээ үгийг сонсож, бүү ид гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир чамаас болж газар хараагдлаа. Чи газар шороондоо буцталаа… учир нь чамайг газар шорооноос

авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцна” гэжээ. Эмэгтэйд хандан Тэрээр: “Жирэмсний чинь зовлон зүдүүрийг Би улам ихэсгэнэ. Өвдөж зовж чи үр хүүхдээ төрүүлнэ. Эр нөхрөө чи эрмэлзэнэ, нөхөр чинь чамайг захирах болно” гэв. Тэр үеэс эхлээд Тэр тэднийг Еден цэцэрлэгээс хөөж, орчин үеийн хүн одоо газар дэлхий дээр амьдардагтай адилаар цэцэрлэгийн гадна амьдруулах болсон юм. Бурхан хүнийг бүр анх бүтээх үедээ, бүтээгдсэнийх нь дараа хүнийг могойгоор уруу татуулаад, дараа нь хүн, могой хоёрыг хараана гэж төлөвлөөгүй байв. Түүнд үнэндээ тийм төлөвлөгөө байгаагүй; ердөө аливаа зүйлийн өрнөл л Түүнд бүтээлүүдийнхээ дунд хийх шинэ ажлыг өгсөн юм. Ехова газар дээр Адам, Евагийн дунд энэ ажлаа гүйцэтгэсний дараа хүн төрөлхтөн хэдэн мянган жилийн турш үргэлжлүүлэн хөгжсөн ба “Ехова, дэлхий дээрх хүмүүсийн хорлонт муу нь үлэмж их бас зүрхнийх нь хамаг бодол санаархал ямагт муу муухай болсныг хараад, Өөрөө хүнийг газар дээр бүтээсэндээ харамсан зүрхэндээ ихэд халаглав… Гэвч Ноа Еховагийн мэлмийд тааллыг олжээ.” Өөрийнх нь бүтээсэн хүн төрөлхтөн могойд уруу татагдсаныхаа дараа хэтэрхий нүгэлтэй болсон учраас энэ үед Еховагийн хийх илүү их шинэ ажил гарч ирсэн юм. Энэ нөхцөл байдлаас болоод Ехова бүх хүн төрөлхтний дундаас Ноагийн гэр бүлийг өршөөхөөр сонгож, дараа нь дэлхийг үерээр устгах ажлаа хэрэгжүүлжээ. Яг энэ өдрийг хүртэл хүн төрөлхтөн ийм байдлаар үргэлжлүүлэн хөгжиж, улам бүр завхарсан ба хүний хөгжил оргилдоо хүрэх цаг ирэхэд энэ нь хүн төрөлхтний төгсгөл байх болно. Дэлхийн яг эхлэлээс төгсгөл хүртэл Түүний ажлын дотоод үнэн үргэлж ийм байсаар ирсэн бөгөөд үргэлж ийм байна. Энэ нь хүмүүс төрлийнхөө дагуу ангилагдахтай адилхан байх болно; хүн нэг бүр тодорхой ангилалд харьяалагдахаар бүр анхнаасаа урьдчилан тогтоогддог юм огт биш; харин ч хөгжлийн үйл явцыг туулсныхаа дараа л хүн болгон аажмаар ангилагддаг. Эцэст нь, бүрэн аврал хүртэж чадахгүй хэн боловч “өвөг дээдсүүд” рүүгээ буцан очно. Хүн төрөлхтний дундах Бурханы ажлын аль нь ч дэлхий бүтээгдэх үед хэдийнээ бэлтгэгдсэн байгаагүй; харин энэ бол хүн төрөлхтний дундах ажлаа алхам алхмаар илүү бодитой, жинхэнэ байдлаар хэрэгжүүлэх боломжийг Бурханд олгосон зүйлсийн хөгжил юм. Жишээ нь, Ехова Бурхан эмэгтэй хүнийг уруу татуулахын тулд могойг бүтээгээгүй; тэр нь Түүний тусгай төлөвлөгөө байгаагүй, Түүний зориуд урьдчилан төлөвлөсөн зүйл ч байгаагүй. Энэ нь гэнэтийн тохиолдол байсан гэж хэлж болно. Тиймээс, үүнээс болоод Ехова, Адам Ева хоёрыг Еден цэцэрлэгээс хөөж, дахин хэзээ ч хүнийг бүтээхгүй гэж амласан юм. Гэхдээ энэ суурин дээр л хүмүүс Бурханы мэргэн ухааныг олж мэддэг. Урьд нь Миний хэлсэнчлэн: “Би Сатаны явуулгад үндэслэн мэргэн ухаанаа хэрэгжүүлдэг.” Хүн төрөлхтөн хэчнээн завхарсан ч бай, эсвэл могой тэднийг хэрхэн уруу татсан ч бай, Еховад мэргэн ухаан нь байсаар байдаг; тийм болохоор Тэр дэлхий ертөнцийг бүтээснээсээ хойш шинэ ажил эрхэлсэн ба энэхүү ажлын нэг ч алхам хэзээ ч давтагдаж байгаагүй. Сатан тасралтгүй явуулга хийж, хүн төрөлхтнийг байнга завхруулсаар ирсэн ба Ехова Бурхан Өөрийн ухаалаг

ажлыг зогсолтгүй явуулсан билээ. Тэр хэзээ ч бүтэлгүйтээгүй, мөн дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш ажиллахаа хэзээ ч болиогүй. Хүмүүсийг Сатан завхруулсны дараа Тэрээр хүн төрөлхтний завхралын эх сурвалж болсон дайсныг ялахын тулд хүмүүсийн дунд ажилласаар байсан юм. Энэхүү тулаан дэлхийн үүслээс эхлэн өрнөсөн ба дэлхий ертөнцийн төгсгөл хүртэл үргэлжилнэ. Энэ бүх ажлыг хийхдээ Ехова Бурхан Сатанаар завхруулагдсан хүмүүст Өөрийн агуу авралыг хүртээгээд зогсохгүй, мөн тэдэнд Өөрийн мэргэн ухаан, төгс хүчин, эрх мэдлийг харуулсан. Түүнчлэн, эцэст нь Тэрээр тэдэнд зөвт зан чанараа харуулж—хорон мууг шийтгэн, сайныг шагнана. Тэр яг энэ өдрийг хүртэл Сатантай тулалдсан ба хэзээ ч ялагдаагүй. Учир нь Тэр бол ухаалаг Бурхан бөгөөд Түүний мэргэн ухаан Сатаны явуулгад үндэслэн хэрэгждэг. Тиймээс Бурхан тэнгэр дэх бүх зүйлийг Өөрийн эрх мэдэлд захирагдуулаад зогсохгүй, бас газар дээрх бүх зүйлийг хөлийнхөө гишгүүр дор амраадаг, ялангуяа хүн төрөлхтөн рүү дайран довтолж, зовоодог хорон муу хүмүүсийг Өөрийн гэсгээлтэд унагадаг. Энэ бүх ажлын үр дүн нь Түүний мэргэн ухаанаас үүдэн гардаг. Хүн төрөлхтний оршин тогтнолоос өмнө Тэр хэзээ ч Өөрийн мэргэн ухааныг илчлээгүй, учир нь Түүнд тэнгэрт ч, газар дээр ч, эсвэл бүх орчлон ертөнцийн хаана ч ямар ч дайсан байгаагүй бөгөөд байгаль дээрх ямар нэг зүйлд халдан довтолсон харанхуй хүчнүүд байгаагүй юм. Тэргүүн тэнгэрэлчийг Өөрөөс нь урвасны дараа Тэрээр хүн төрөлхтнийг газар дээр бүтээсэн ба хүн төрөлхтнөөс болоод Тэр тэргүүн тэнгэрэлч болох Сатантай хийсэн мянган жилийн дайнаа—ээлж дараалсан үе шат бүрд улам эрчимждэг дайныг албан ёсоор эхлүүлсэн юм. Түүний төгс хүчин болон мэргэн ухаан энэ үе шат болгонд байсан. Тэр үед л тэнгэр, газар дахь бүх зүйл Бурханы мэргэн ухаан, төгс хүчин, ялангуяа Бурханы бодит байдлыг харсан юм. Тэр өнөөдөр ч ийм бодит байдлаар Өөрийн ажлыг хэрэгжүүлсээр байгаа; түүнчлэн, Тэрээр Өөрийн ажлыг хэрэгжүүлэнгээ мэргэн ухаан, төгс хүчээ ч бас илчилдэг. Тэрээр та нарт ажлын үе шат бүрийн дотоод үнэнийг харуулж, Бурханы төгс хүчийг яг яаж тайлбарлахыг харуулахын сацуу Бурханы бодит байдлын тодорхой тайлбарыг харуулдаг.

Иудас Есүсээс урвасан тухайд, энэ нь дэлхий ертөнцийг бүтээхээс өмнө урьдчилан тодорхойлогдсон байсан бус уу гэж зарим хүн гайхдаг. Үнэндээ тухайн үеийн бодит байдалд үндэслэн Ариун Сүнс үүнийг төлөвлөсөн юм. Харин үргэлж мөнгө хөрөнгө завшиж байсан Иудас гэдэг нэртэй хүн тэнд байж таарсан тул уг хүн энэ дүрд тоглож, ийм маягаар үйлчлэхээр сонгогдсон. Энэ нь тухайн үеийн эх сурвалжийг ашигласан жинхэнэ жишээ байлаа. Есүс эхэндээ энэ талаар мэдээгүй; Тэрээр сүүлд нь Иудасыг илчлэгдсэний дараа л энэ тухай мэдсэн. Хэрвээ өөр хэн нэгэн энэ дүрд тоглож чадах байсан бол Иудасын оронд тэр хүн үүнийг хийх байв. Урьдчилан тогтоогдсон зүйл нь үнэндээ тухайн хоромд Ариун Сүнсний хийсэн зүйл байсан юм. Ариун Сүнсний ажил үргэлж аяндаа хийгддэг; Тэр Өөрийн ажлыг хэдийд ч төлөвлөж, хэдийд ч биелүүлж чадна. Ариун Сүнсний ажил бодитой, үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй, үргэлж хамгийн шинэхэн байдаг гэж

Би яагаад үргэлж хэлдэг вэ? Дэлхий ертөнц бүтээгдэх үед Түүний ажил аль хэдийн төлөвлөгдсөн байгаагүй; ийм зүйл огт болоогүй! Ажлын алхам бүр нь тус тусын цаг хугацаандаа зүй зохистой үр дүндээ хүрдэг ба алхмууд нь нэг нэгэндээ саад болдоггүй. Маш олон удаа, чиний оюун санаан дахь төлөвлөгөө Ариун Сүнсний хамгийн сүүлийн үеийн ажилтай ердөө дүйцдэггүй. Түүний ажил хүний боддог шиг энгийн байдаггүй, хүний төсөөлдөг шиг төвөгтэй ч байдаггүй—энэ нь хүмүүсийн тухайн үеийн хэрэгцээнд нийцүүлэн хэдийд ч, хаана ч хүмүүсийг хангахаас бүрдэнэ. Хүмүүсийн мөн чанарыг Түүн шиг тодорхой мэддэг хэн ч байхгүй бөгөөд яг энэ шалтгааны улмаас хүмүүсийн бодит хэрэгцээнд Түүний ажил шиг тохирч чадах зүйл юу ч үгүй. Тиймээс хүний үзэл бодлоор бол Түүний ажил хэдэн мянган жилийн өмнөөс урьдчилан төлөвлөгдсөн мэт санагддаг. Одоо та нарын дунд ажиллаж, та нарын байгаа байдлыг ажиглангаа ажиллаж, үг хэлж байх зууraa Тэр янз бүрийн байр байдалтай тулгараад яг оносон үг хэлдэг ба хүмүүст яг хэрэгтэй байгаа үгийг хэлдэг. Түүний ажлын эхний алхам буюу гэсгээлтийн цаг үеийг аваад үз. Үүний дараа, Бурхан хүмүүсийн харуулж байсан зүйл буюу тэдний эсэргүүцэл, тэднээс гарч ирсэн эерэг байдал, сөрөг байдал, түүнчлэн тэдгээр сөрөг байдал тодорхой нэг цэгт хүрэх үед хүмүүсийн унах хамгийн доод хязгаарт үндэслэн ажлаа явуулсан; Тэрээр Өөрийнхөө ажлаар илүү дээр үр дүнд хүрэхийн тулд эдгээр зүйлийг ашигласан. Өөрөөр хэлбэл, Тэрээр тухайн нэг хугацаан дахь хүмүүсийн байгаа байдалд үндэслэн хүмүүсийг хангах ажлаа хийдэг; Тэрээр Өөрийн ажлын алхам бүрийг хүмүүсийн бодит байр байдлын дагуу хэрэгжүүлдэг. Бүх бүтээл Түүний гарт байдаг; Тэр яаж тэднийг мэдэхгүй байж болох юм бэ? Бурхан хүмүүсийн байр байдалд нийцүүлэн, хийгдэх ёстой ажлын дараагийн алхмыг хэдийд ч, хаана ч хэрэгжүүлдэг. Энэ ажил яавч олон мянган жилийн өмнөөс төлөвлөгдөөгүй; энэ нь хүний үзэл юм! Тэрээр Өөрийн ажлын үр нөлөөг ажиглангаа ажилладаг ба Түүний ажил тасралтгүй гүнзгийрч, хөгжиж байдаг; Өөрийн ажлын үр дүнг ажигласныхаа дараа Тэрээр тухай бүрд нь ажлынхаа дараагийн алхмыг хэрэгжүүлдэг. Тэр аажмаар шилжихийн тулд олон зүйлийг ашигладаг ба цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Өөрийн шинэ ажлыг хүмүүст илэрхий болгодог. Ийм байдлаар ажиллах нь хүмүүсийн хэрэгцээг хангаж чадна, учир нь Бурхан хүмүүсийг дэндүү сайн мэддэг билээ. Ийнхүү Тэр Өөрийн ажлыг тэнгэрээс хэрэгжүүлдэг. Үүний адилаар, бие махбодтой болсон Бурхан ийм маягаар ажлаа хийж, бодит нөхцөл байдлын дагуу зохицуулалт хийж, хүмүүсийн дунд ажилладаг. Дэлхий ертөнцийг бүтээхээс өмнө Түүний ажлын аль нь ч зохицуулагдсан байгаагүй, мөн урьдчилан нарийн нямбай төлөвлөгдсөн ч байгаагүй. Дэлхий бүтээгдсэнээс хойш хоёр мянган жилийн дараа хүн төрөлхтөн маш их завхарсныг Ехова харсан болохоор эш үзүүлэгч Исаиагийн амыг ашиглан, Хуулийн эрин үе дууссаны дараа Нигүүлслийн эрин үед Ехова хүн төрөлхтнийг золин аврах ажлаа явуулна хэмээн зөгнөсөн. Энэ нь Еховагийн төлөвлөгөө байсан, мэдээж энэхүү төлөвлөгөө ч бас тухайн үед Түүний ажигласан нөхцөл байдлын дагуу хийгдсэн; Тэрээр Адамыг

бүтээснийхээ яг дараахан энэ тухай бодоогүй нь лавтай. Исаиа ердөө л зөгнөл хэлсэн, харин Ехова Хуулийн эрин үед үүнд зориулаад урьдчилан бэлтгээгүй; харин ч Тэр үүнийг Нигүүлслийн эрин үеийн эхэнд хийж эхэлсэн ба Иосефийн зүүдэнд элч харагдаж, Бурхан махбод болно гэх мэдээгээр түүнийг гэгээрүүлэх үед л Түүний бие махбодтой болох ажил нь эхэлсэн. Хүмүүсийн төсөөлдөг шигээр Бурхан энэ дэлхийг бүтээснийхээ яг дараа бие махбодтой болох ажилдаа бэлтгээгүй; энэ нь хүн төрөлхтний хөгжлийн хэмжээ болон Сатантай хийсэн Түүний дайны төлөв байдлын дагуу л шийдэгдсэн юм.

Бурхан махбод болох үед Түүний Сүнс хүн дээр бууж ирдэг; өөрөөр хэлбэл, Бурханы Сүнс бие махбодоор хувцасладаг. Тэрээр зарим тодорхой хязгаарлагдмал алхмуудыг авчралгүйгээр Өөрийн ажлыг газар дээр хийхээр ирдэг; Түүний ажил ямар ч хязгааргүй байдаг. Ариун Сүнсний махбодоор хийдэг ажил мөн л Түүний ажлын үр дүнгээр тодорхойлогддог ба Тэрээр махбодод байхдаа ажлаа хэр удаан хугацаанд хийхээ тодорхойлохын тулд ийм зүйлсийг ашигладаг. Ариун Сүнс ажлынхаа алхам бүрийг шууд илчилдэг ба явахынхаа хэрээр Өөрийн ажлыг шинжилж шалгадаг; энэхүү ажил хүний төсөөллийн хязгаараас даван гарахуйц тийм ч ер бусын биш. Энэ нь тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн Еховагийн ажилтай адилхан; Тэр нэгэн зэрэг төлөвлөж, ажилласан. Тэр гэрлийг харанхуйгаас салгаад, өглөө, орой бий болсон—үүнд нэг өдрийг зарцуулжээ. Хоёр дахь өдөр нь Тэрээр тэнгэрийг бүтээсэн ба үүнд мөн нэг өдрийг зарцуулсан; дараа нь газар дэлхий, далай тэнгис, болон тэдгээрт суурьших бүх бүтээлийг бүтээхэд мөн л нэг өдөр шаардагдсан юм. Энэ нь зургаа дахь өдрийг хүртэл үргэлжилсэн ба тэр үед Бурхан хүнийг бүтээгээд газар дээрх бүх зүйлийг түүгээр удирдуулжээ. Тэгээд долоо дахь өдөр нь Тэр бүх зүйлийг бүтээж дуусаад амарсан юм. Бурхан долоо дахь өдрийг ерөөж, үүнийг ариун өдөр болгон тогтоосон. Тэрээр бүх зүйлийг бүтээхээсээ өмнө биш, харин аль хэдийн бүтээснийхээ дараа энэхүү ариун өдрийг тогтоохоор шийдсэн билээ. Энэ ажил ч бас аяндаа хийгдсэн; бүх зүйлийг бүтээхээсээ өмнө Тэр дэлхийг зургаан өдөрт бүтээгээд долоо дахь өдөр нь амарна гэж шийдээгүй байсан; энэ нь бодит баримттай огтхон ч нийцдэггүй. Тэр ийм зүйл хэлээгүй, ингэж ч төлөвлөөгүй. Бүх зүйлийн бүтээл нь зургаа дахь өдөр дуусаад, долоо дахь өдөр нь амарна гэж Тэр яавч хэлээгүй; харин тухайн үед Өөрт нь юу сайн санагдаж байсны дагуу л бүтээсэн. Тэр бүх зүйлийг бүтээж дуусмагц аль хэдийн зургаа дахь өдөр болсон байв. Хэрвээ бүх зүйлийг бүтээж дуусахад тав дахь өдөр байсан бол Тэрээр зургаа дахь өдрийг ариун өдөр болгон тогтоох байлаа. Гэхдээ Тэр үнэндээ бүх зүйлийг зургаа дахь өдөр бүтээж дууссан ба тийнхүү долоо дахь өдөр нь ариун өдөр болж, өнөөдрийг хүртэл уламжлагдан иржээ. Тиймээс, Түүний одоогийн ажил үүнтэй адилаар хийгдэж байгаа. Тэр та нарын нөхцөл байдлын дагуу хэрэгцээг чинь хангаж, үгээ хэлдэг. Өөрөөр хэлбэл, Сүнс хүмүүсийн нөхцөл байдлын дагуу үг хэлж, ажилладаг; Тэр бүхнийг ажиглан харж, хэдийд ч хаана ч ажилладаг. Миний хийдэг, хэлдэг, та нарт үүрүүлж, та нарт

олгож байгаа зүйл бүгд ялгаагүй та нарт хэрэгтэй зүйлс юм. Тиймээс Миний ажлын аль нь ч бодит байдлаас салангид байдаггүй; бүгд бодитой байдаг, учир нь “Бурханы Сүнс бүгдийг ажиглан харж байдаг” гэдгийг та нар бүгд мэднэ. Хэрвээ энэ нь бүгд цагаасаа өмнө шийдэгдсэн байсан бол хэтэрхий төлөвлөгдсөн байх бус уу? Бурхан бүхэл бүтэн зургаан мянган жилийн төлөвлөгөөг гаргасан, дараа нь хүн төрөлхтнийг тэрслүү, эсэргүү, шударга бус, зальжин, махан биеийн завхрал, сатанлаг зан чанар, нүдний шунал тачаал, хувийн дур сонирхолтой байхаар урьдчилан төлөвлөсөн гэж чи боддог. Эдгээрийн алийг нь ч Бурхан урьдчилан төлөвлөөгүй, харин Сатан завхруулснаас болоод энэ бүхэн тохиолдсон юм. Зарим хүн: “Сатан ч бас Бурханы атганд байсан бус уу? Сатан ийм байдлаар хүнийг завхруулна, дараа нь хүмүүсийн дунд Өөрийн ажлыг явуулна гэж Бурхан урьдчилан төлөвлөсөн” хэмээн хэлж магадгүй. Сатан хүн төрөлхтнийг завхруулна гэдгийг Бурхан үнэхээр урьдчилан төлөвлөх үү? Бурхан хүн төрөлхтнийг хэвийн амьдруулахыг л хүсэн эрмэлздэг тул тэдний амьдралд үнэхээр хөндлөнгөөс оролцоно гэж үү? Тэгэх юм бол Сатаныг ялж, хүн төрөлхтнийг аврах нь хий дэмий хичээл чармайлт болох бус уу? Хүн төрөлхтний тэрслүү байдлыг урьдчилан төлөвлөсөн байж яаж болох юм бэ? Энэ нь Сатаны хөндлөнгийн оролцооноос болж тохиолдсон зүйл юм; үүнийг Бурхан урьдчилан төлөвлөсөн байж яаж болох юм бэ? Та нарын бодож байгаа Бурханы атган дахь Сатан болон Миний ярьж байгаа Бурханы атган дахь Сатан маш өөр. Та нарын “Бурхан төгс хүчтэй бөгөөд Сатан түүний гарт байдаг” гэж хэлдгийн дагуу бол Сатан Түүнээс хэзээ ч урваж чадахгүй. Бурхан төгс хүчтэй гэж чи хэлсэн бус уу? Та нарын мэдлэг хэтэрхий хийсвэр ба бодит байдалтай үл тохирдог; хүн Бурханы бодлыг ухан ойлгож хэзээ ч чадахгүй, Бурханы мэргэн ухааныг ойлгож хэзээ ч чадахгүй! Бурхан бол төгс хүчтэй; энэ нь огтхон ч худлаа биш. Бурхан анх түүнд эрх мэдлийн нэг хувийг өгсөн учраас тэргүүн тэнгэрэлч Бурханаас урвасан юм. Мэдээж энэ нь Ева могойн уруу таталтад автсантай адил гэнэтийн явдал байсан. Гэвч Сатан урвалтаа яаж явуулах нь хамаагүй, тэр Бурхантай адил төгс хүчтэй биш. Та нарын хэлснээр, Сатан ердөө л хүчирхэг; тэр юу хийх нь хамаагүй, Бурханы эрх мэдэл түүнийг үргэлж ялна. Энэ бол “Бурхан төгс хүчтэй бөгөөд Сатан Түүний гарт байдаг” гэсэн үгийн цаана буй жинхэнэ утга билээ. Тиймээс, Сатантай хийх дайн нэг удаад нэг алхмаар явагдах ёстой. Түүнчлэн, Сатаны ов мэхийн хариуд Бурхан Өөрийн ажлыг төлөвлөдөг—өөрөөр хэлбэл, Тэрээр эрин үед тохирсон байдлаар хүмүүст аврал авчирч, төгс хүчин, мэргэн ухаанаа илчилдэг. Үүнтэй адилаар, эцсийн өдрүүд дэх ажлыг Нигүүлслийн эрин үеэс өмнө урьдчилан төлөвлөөгүй юм; урьдчилан төлөвлөлт нь: нэгдүгээрт, хүний гадаад зан чанарыг өөрчилнө; хоёрдугаарт, хүнийг гэсгээлт, шалгалтад өртүүлнэ; гуравдугаарт, хүнээр үхлийн шалгалт туулуулна; дөрөвдүгээрт, Бурханыг хайрлах цаг үеийг хүнээр туулуулж, бүтээгдсэн зүйлийн шийдвэрийг илэрхийлүүлнэ; тавдугаарт, Бурханы хүслийг хүнд харуулж, Бурханыг бүрэн мэдүүлж, эцэст нь хүнийг бүрэн төгс болгоно гэсэн байдлаар эмх цэгцтэйгээр

хийгддэггүй. Тэр энэ бүх зүйлийг Нигүүлслийн эрин үед төлөвлөөгүй; харин Тэрээр өнөө үед эдгээрийг төлөвлөж эхэлсэн юм. Сатан ажиллаж байгаа, Бурхан ч мөн адил. Сатан завхарсан зан чанараа илэрхийлдэг байхад Бурхан шууд ярьж, мөн чанарын зарим зүйлийг илчилдэг. Энэ бол өнөөдөр хийгдэж байгаа ажил бөгөөд үүнтэй адил төрлийн ажиллах зарчим дэлхийг бүтээгдсэний дараа аль эртнээс хэрэглэгдэж байсан юм.

Эхлээд Бурхан Адам, Еваг бүтээсэн ба бас могойг бүтээсэн. Бүх зүйлийн дотроос энэхүү могой хамгийн хортой нь байв; үүний бие хор агуулж байсан ба могойг далимдуулан ашиглахын тулд Сатан хорыг нь хэрэглэжээ. Могой Еваг уруу татан нүгэл үйлдүүлсэн юм. Евагийн дараа Адам нүгэл үйлдсэн ба дараа нь тэр хоёр сайн мууг ялган таньж чаддаг болжээ. Могой Еваг уруу татаж, Ева Адамыг уруу татна гэдгийг Ехова мэдэж байсан бол яагаад тэднийг бүгдийг нь цэцэрлэг дотор тавьсан юм бэ? Хэрвээ Тэр эдгээр зүйлийг урьдчилан таамаглаж чадсан бол яагаад могойг бүтээгээд, Еден цэцэрлэг дотор тавьсан юм бэ? Яагаад Еден цэцэрлэгт сайн мууг мэдүүлэгч модны жимс байсан бэ? Тэр тэдэнд жимсийг идүүлэх гээгүй гэж үү? Еховаг ирэхэд Адам ч, Ева ч Түүнтэй нүүр тулж зүрхлээгүй ба тэр үед л, сайн мууг мэдүүлэгч модны жимсийг идэж, могойн арга зальд автсаныг нь Ехова мэдсэн. Эцэст нь Тэр могойг харааж, Адам Ева хоёрыг ч бас хараажээ. Тэр хоёрыг модны жимснээс идэх үед Ехова юу хийж байгааг нь огт мэдээгүй. Хүн төрөлхтөн ёрын муу, садар самуун болох хүртлээ завхарч, тэр ч байтугай зүрх сэтгэлдээ өвөрлөсөн бүхэн нь ёрын муу, зөв шударга бус болохдоо тулсан; энэ нь бүгд бузар байсан. Тиймээс Ехова хүн төрөлхтнийг бүтээсэндээ харамссан юм. Үүний дараа Тэр дэлхийг үерээр устгах ажлаа хэрэгжүүлсэн ба үүнээс Ноа болон түүний хөвгүүд амьд үлдсэн билээ. Зарим зүйл үнэндээ хүмүүсийн төсөөлдөг шиг тийм ч ахисан түвшинтэй, ер бусын байдаггүй. Зарим хүн: “Тэргүүн тэнгэрэлч Өөрөөс нь урвана гэдгийг Бурхан мэдэж байсан байж яагаад үүнийг бүтээсэн юм бэ?” гэж асуудаг. Эдгээр нь бодит баримт: Газар дэлхий хараахан оршин тогтноогүй байх үед тэргүүн тэнгэрэлч тэнгэрийн тэнгэрэлчүүдээс хамгийн том нь байсан юм. Энэ нь тэнгэр дэх бүх тэнгэрэлчийг захирч байсан; энэ нь Бурханы олгосон эрх мэдэл байв. Бурханыг оролцуулахгүйгээр тэрээр тэнгэрэлчүүдээс хамгийн том нь байсан. Хожим нь Бурхан хүн төрөлхтнийг бүтээсний дараа тэргүүн тэнгэрэлч Бурханы эсрэг бүр ч том урвалтыг газар дээр үйлджээ. Энэ нь хүн төрөлхтнийг удирдаж, Бурханы эрх мэдлээс давахыг хүссэн учраас Бурханаас урвасан гэж Би хэлдэг. Тэргүүн тэнгэрэлч Еваг нүгэлд уруу татсан бөгөөд өөрийн хаанчлалыг газар дээр байгуулж, хүн төрөлхтнийг Бурханаас урвуулж, оронд нь өөртөө дуулгавартай байлгахыг хүссэн учраас ингэсэн юм. Өөрийг нь дуулгавартай дагаж чадах маш олон зүйл байгааг тэргүүн тэнгэрэлч харсан—тэнгэрэлчүүд, газар дээрх хүмүүс ч бас түүнд дуулгавартай байж чадах байсан. Араатан, шувууд, модод, ой шугуй, уулс, гол болон газар дээрх бүх зүйл хүмүүсийн буюу Адам, Ева хоёрын халамжид байсан, харин Адам, Ева хоёр

тэргүүн тэнгэрэлчид дуулгавартай байсан. Тиймээс тэргүүн тэнгэрэлч Бурханы эрх мэдлийг давж, Бурханаас урвахыг хүсжээ. Дараа нь тэр олон тэнгэрэлчийг Бурханы эсрэг тэрслэхэд хүргэсэн ба тэгээд тэд хожим нь янз бүрийн бузар сүнснүүд болсон юм. Өнөөдрийг хүртэлх хүн төрөлхтний хөгжил тэргүүн тэнгэрэлчийн завхралаас үүдээгүй гэж үү? Тэргүүн тэнгэрэлч Бурханаас урваж, хүн төрөлхтнийг завхруулсан учраас л хүмүүс өнөөдөр ийм байдалтай байгаа юм. Энэхүү алхам алхмаар хийгддэг ажил нь хүмүүсийн төсөөлдөг шиг хийсвэр бөгөөд энгийн огт биш. Сатан тодорхой учир шалтгаантайгаар урвасан, гэсэн ч хүмүүс ийм энгийн зүйлийг ойлгож чаддаггүй. Тэнгэр, газар болон бүх зүйлийг бүтээсэн Бурхан яагаад бас Сатаныг бүтээсэн юм бэ? Бурхан Сатаныг маш их үзэн яддаг тул Сатан бол Түүний дайсан, тэгвэл Тэр яагаад Сатаныг бүтээсэн юм бэ? Сатаныг бүтээснээрээ Тэр дайсныг бүтээсэн бус уу? Бурхан үнэндээ дайсныг бүтээгээгүй юм; харин ч Тэрээр тэнгэрэлчийг бүтээсэн ба дараа нь тэнгэрэлч Түүнээс урвасан билээ. Өөрийнх нь байр суурь маш өндөр болсон учраас тэр Бурханаас урвахыг хүсжээ. Энэ нь тохиолдлын хэрэг байсан гэж хэлж болох боловч энэ нь бас зайлшгүй байдал байлаа. Хүн тодорхой хэмжээнд хүртэл өсөж төлөвшсөнийхөө дараа зайлшгүй нас бардагтай энэ нь адилхан; юмс яг тэр үе шат хүртэл хөгжсөн. Зарим хөгийн мунхаг хүмүүс: “Сатан Таны дайсан байхад Та яагаад үүнийг бүтээсэн юм бэ? Тэргүүн тэнгэрэлч Танаас урвана гэдгийг Та мэдээгүй гэж үү? Та мөнхөөс мөнхөд харж чаддаггүй гэж үү? Та тэргүүн тэнгэрэлчийн уг чанарыг мэдээгүй гэж үү? Энэ нь Танаас урвана гэдгийг тодорхой мэдэж байсан байж Та яагаад үүнийг тэргүүн тэнгэрэлч болгосон юм бэ? Энэ нь Танаас урваад зогсохгүй, хүн төрөлхтнийг завхруулахын тулд маш олон тэнгэрэлчийг удирдан мөнх бусын ертөнцөд бууж ирсэн, гэтэл өнөөдрийг хүртэл Та зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө дуусгаж чадаагүй л байна” гэж хэлдэг. Эдгээр үг зөв үү? Ийм маягаар бодох үедээ чи өөртөө дэмий төвөг удаж байгаа бус уу? Бас, “Сатан хүн төрөлхтнийг өнөөдрийг хүртэл завхруулаагүй бол Бурхан хүн төрөлхтөнд ийм аврал авчрахгүй байх байсан. Тэгсэн бол Бурханы мэргэн ухаан, төгс хүчин харагдахгүй байх байсан; Түүний мэргэн ухаан хаана илчлэгдэх юм бэ? Тиймээс Бурхан хүн төрөлхтнийг Сатаны төлөө бүтээсэн, ингэснээр Тэр дараа нь Өөрийн төгс хүчийг илчилж чадах байсан—тэгэхгүй бол хүн Бурханы мэргэн ухааныг яаж олж мэдэж чадах юм бэ? Хэрвээ хүн Бурханыг эсэргүүцээгүй, Түүний эсрэг тэрслээгүй бол Түүний үйл хэрэг илчлэгдэх шаардлагагүй байсан. Хэрвээ бүх бүтээл Түүнд шүтэн мөргөж, дуулгавартай байсан бол Түүнд хийх ажил байхгүй байх байсан” гэж хэлдэг хүмүүс ч бий. Энэ нь бодит байдлаас бүр ч хол хөндий юм, учир нь Бурхан огт бузар биш учраас бузрыг бүтээж чадахгүй. Тэрээр дайснаа ялж, Өөрийн бүтээсэн хүмүүсийг аварч, Өөрийг нь үзэн яддаг, эсэргүүцдэг, Өөрөөс нь урвадаг бөгөөд хамгийн анх Өөрийнх нь ноёрхол дор байж, бүр анхнаасаа Өөрт нь харьяалагдаж байсан чөтгөрүүд болон Сатаныг ялахын тулд л үйл хэргээ илчилдэг. Бурхан эдгээр чөтгөрийг ялахыг хүсдэг ба ингэснээрээ Өөрийн төгс

хүчийг бүх зүйлд илчилдэг. Хүн төрөлхтөн болоод газар дээрх бүх зүйл одоо Сатаны эзэмшил дор байдаг ба хорон санаатны эзэмшил дор оршдог. Хүмүүс Өөрийг нь мэдэж, улмаар Сатаныг ялж, Түүний дайснуудыг бүрмөсөн ялан дийлэг гэсэндээ Бурхан Өөрийн үйл хэргийг бүх зүйлд илчлэхийг хүсдэг. Өөрийн үйл хэргийг илчилснээр энэ ажлыг бүхэлд нь гүйцэлдүүлдэг. Өөрийнх нь бүх бүтээл Сатаны эзэмшил дор байдаг тул Бурхан тэдэнд Өөрийн төгс хүчийг илчилж, улмаар Сатаныг ялахыг хүсдэг. Хэрвээ Сатан байгаагүй бол Тэр Өөрийн үйл хэргийг илчлэх хэрэггүй байх байв. Сатаны хөндлөнгийн оролцоо байгаагүй бол Бурхан хүн төрөлхтнийг бүтээгээд Еден цэцэрлэгт амьдруулах байсан юм. Сатаны урвалтаас өмнө Бурхан яагаад Өөрийн бүх үйл хэргийг тэнгэрэлчүүд юм уу тэргүүн тэнгэрэлчид хэзээ ч илчлээгүй юм бэ? Хэрвээ тэнгэрэлчүүд болон тэргүүн тэнгэрэлч Бурханыг мэддэг, Түүнд дуулгавартай байдаг байсан бол Бурхан тэдгээр утга учиргүй ажлыг хэрэгжүүлэх хэрэггүй байх байлаа. Сатан болон чөтгөрүүдийн оршин тогтнолын улмаас хүмүүс ч бас Бурханыг эсэргүүцэж, тэрслүү зан чанараар бялхдаг. Тиймээс Бурхан Өөрийн үйл хэргийг илчлэхийг хүсдэг. Тэр Сатантай дайн хийхийг хүсдэг учраас Сатаныг ялахын тулд Өөрийн эрх мэдэл болон бүх үйл хэргийг ашиглах ёстой; ийм маягаар, хүмүүсийн дунд Түүний явуулдаг авралын ажил нь хүмүүст Түүний мэргэн ухаан, төгс хүчийг харуулна. Бурханы өнөөдөр хийж байгаа ажил утга учиртай бөгөөд “Таны хийдэг ажил зөрчилдөөнтэй бус уу? Ажлын энэ дэс дараалал чинь зүгээр л Өөртөө төвөг удсан хэрэг биш үү? Та Сатаныг бүтээсэн, тэгээд Танаас урваж, Таныг эсэргүүцэх боломжийг үүнд олгосон. Та хүмүүсийг бүтээгээд дараа нь тэднийг Сатанд гардуулан өгч, Адам Ева хоёрыг уруу таталтад өртүүлсэн. Та энэ бүх зүйлийг зориуд хийчхээд яагаад хүн төрөлхтнийг жигшсээр байдаг юм бэ? Яагаад Та Сатаныг үзэн яддаг юм бэ? Энэ бүхэн нь Таны хийсэн зүйл биш гэж үү? Танд үзэн ядах юм юу байгаа юм бэ?” гэж зарим хүний хэлдэгтэй яавч адилгүй. Нэлээд олон мунхаг хүн тийм зүйл хэлнэ. Тэд Бурханыг хайрлахыг хүсдэг боловч сэтгэлийнхээ гүнд Бурханы талаар гомдоллодог. Хэчнээн зөрчилдөөнтэй вэ! Чи үнэнийг ойлгодоггүй, хэтэрхий олон ер бусын бодолтой байдаг ба тэр ч байтугай Бурхан алдаа гаргасан гэдэг—чи ямар хөгийн юм бэ! Үнэнээр тоглодог хүн бол чи; харин Бурхан алдаа гаргасан юм биш! Зарим хүн бүр ахин дахин гомдоллож, “Та Сатаныг бүтээсэн, Та Сатаныг хүмүүсийн дунд шидэж, тэднийг Сатанд өгсөн. Хүмүүс сатанлаг зан чанартай болмогц Та тэднийг уучлаагүй; харин оронд нь тодорхой хэмжээнд тэднийг үзэн ядсан. Эхэндээ Та тэднийг тодорхой хэмжээнд хайрласан, гэтэл одоо тэднийг жигшдэг. Та хүн төрөлхтнийг үзэн ядсан, гэхдээ Та бас хүн төрөлхтнийг хайрласан. Яг юу болоод байгаа юм бэ? Энэ нь зөрчилдөөн бус уу?” гэдэг. Та нар үүнийг хэрхэн харахаас үл хамааран, энэ нь тэнгэрт болсон зүйл; ийм байдлаар тэргүүн тэнгэрэлч Бурханаас урваж, хүн төрөлхтөн завхарсан ба хүмүүс ингэж өнөөг хүртэл үргэлжлүүлсэн. Та нар үүнийг яаж илэрхийлэхээс үл хамааран бүхий л түүх бол энэ. Гэвч, та нарыг аврахын тулд, Сатаныг ялахын тулд Бурханы өнөөдөр хийж буй ажлын цаад зорилгыг та нар ойлгох ёстой.

Тэнгэрэлчүүд нэн сул дорой, яриад байх ямар ч чадваргүй байсан учраас эрх мэдэл өгөнгүүт биеэ тоож эхэлсэн. Ялангуяа бусад тэнгэрэлчээс өндөр байр суурьтай байсан тэргүүн тэнгэрэлчийн хувьд ийм байсан юм. Тэнгэрэлчүүдийн дундах хаан тэрээр олон сая тэнгэрэлчийг удирдан захирч байсан ба Еховагийн дор түүний эрх мэдэл өөр ямар ч тэнгэрэлчийнхээс давжээ. Тэрээр энэ, тэрийг хийхийг хүсэж, дэлхийг хянахын тулд хүний ертөнц рүү тэнгэрэлчүүдийг удирдан буухыг хүссэн юм. Бурхан Өөрийгөө орчлон ертөнцийг захирдаг Нэгэн гэж хэлсэн; гэтэл тэргүүн тэнгэрэлч өөрийгөө орчлон ертөнцийг захирдаг гэж хэлсэн—тэр үеэс хойш тэргүүн тэнгэрэлч Бурханаас урвасан юм. Бурхан тэнгэрт өөр ертөнцийг бүтээсэн бөгөөд тэргүүн тэнгэрэлч энэ ертөнцийг захирахын сацуу мөнх бусын ертөнцөд буухыг хүссэн. Бурхан ингэхийг нь зөвшөөрч чадна гэж үү? Тиймээс Тэр тэргүүн тэнгэрэлчийг цохиж, агаар луу доош шидсэн юм. Хүмүүсийг завхруулснаас нь хойш тэднийг аврахын тулд Бурхан Сатантай дайтах болсон; Тэр түүнийг ялахын тулд энэ зургаан мянганыг ашигласан юм. Та нарын үзлээр бол Бурхан төгс хүчтэй байдаг бөгөөд Бурханы одоо явуулж байгаа ажилтай нийцдэггүй; энэ нь туйлын бодит бус бөгөөд маш утгагүй! Үнэндээ тэргүүн тэнгэрэлчийг урвасны дараа л Бурхан түүнийг дайснаа гэж зарласан. Урвалтынхаа улмаас л тэргүүн тэнгэрэлч мөнх бусын ертөнцөд ирснийхээ дараа хүн төрөлхтнийг гишгэлсэн ба энэ шалтгааны улмаас хүн төрөлхтөн өдийг хүртэл хөгжсөн билээ. Ийм юм тохиолдсоны дараа Бурхан Сатанд: “Би чамайг ялж, Өөрийн бүтээсэн бүх хүнд аврал авчирна” гэж тангарагласан юм. Сатан эхэндээ үнэмшээгүй ба “Та үнэндээ надад юу хийж чадах юм бэ? Та үнэхээр намайг агаар луу цохиж чадна гэж үү? Та үнэхээр Намайг ялж чадна гэж үү?” хэмээн хариулжээ. Бурхан агаар луу цохисныхоо дараа тэргүүн тэнгэрэлчид цаашид анхаарал хандуулаагүй бөгөөд хожим нь Сатаны байнгын үймээнийг үл хайхран хүн төрөлхтнийг аварч, Өөрийн ажлыг хийж эхэлсэн. Сатан энэ, тэрийг хийж чаддаг байсан ч энэ бүхэн нь урьд нь түүнд Бурханы өгсөн эрх мэдлийн ач байв; тэр эдгээрийг өөртөө аван агаарт гарч, өнөөг хүртэл хадгалсаар ирсэн. Тэргүүн тэнгэрэлчийг агаар луу цохихдоо Бурхан эрх мэдлийг нь буцааж аваагүй тул Сатан хүн төрөлхтнийг үргэлжлүүлэн завхруулжээ. Нөгөө талаар, бүтээгдсэнийх нь дараа Сатаны завхруулсан хүн төрөлхтнийг Бурхан аварч эхэлсэн. Бурхан тэнгэрт байхдаа Өөрийн үйл хэргийг илчлээгүй; гэхдээ газар дэлхийг бүтээхээсээ өмнө Тэрээр тэнгэрт бүтээсэн дэлхийнхээ хүмүүст Өөрийн үйл хэргийг харуулж, тэгснээрээ тэнгэр дээрх хүмүүсийг удирдан хөтөлсөн. Тэр тэдэнд мэргэн ухаан, оюуны чадамж өгч, тэрхүү дэлхийд амьдруулахаар тэрхүү хүмүүсийг удирдан хөтөлсөн. Мэдээж та нарын хэн ч энэ тухай өмнө нь сонсож байгаагүй. Дараа нь, Бурхан хүмүүсийг бүтээсний дараа тэргүүн тэнгэрэлч тэднийг завхруулж эхэлсэн; газар дээр бүх хүн төрөлхтөн эмх замбараагүй байдалд автсан. Тэр үед л Бурхан Сатаны эсрэг дайнаа эхлүүлсэн ба тэр үед л хүмүүс Түүний үйл хэргийг харж эхэлсэн билээ. Эхэндээ тийм үйл хэрэг хүн төрөлхтнөөс нуугдмал байв. Агаар луу цохигдсоныхоо дараа Сатан өөрийнхөө юмыг хийж, Бурхан ч Өөрийнхөө ажлыг

үргэлжлүүлэн хийсэн ба эцсийн өдрүүдийг хүртэл Сатантай тасралтгүй дайтсан билээ. Одоо үе бол Сатан устгагдах ёстой цаг үе. Анх Бурхан түүнд эрх мэдэл өгсөн, дараа нь Тэр үүнийг агаар руу цохисон ч тэр эсэргүүцсэн хэвээр үлдсэн. Дараа нь, тэр газар дээр хүн төрөлхтнийг завхруулсан боловч Бурхан тэнд хүн төрөлхтнийг удирдаж байлаа. Сатаныг ялахын тулд Бурхан хүмүүсийг удирдах Өөрийн удирдлагыг ашигладаг. Хүмүүсийг завхруулснаар Сатан тэдний хувь заяаг эцэслэж, Бурханы ажлыг үймүүлдэг. Нөгөө талаар, Бурханы ажил бол хүн төрөлхтний аврал билээ. Бурханы ажлын аль алхам нь хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаггүй вэ? Аль алхам нь хүмүүсийг цэвэрлэж, тэднийг зөв шударга авирладаг болгож, хайр татам хүмүүсийн дүрийг амьдран харуулдаг болгохын төлөө байдаггүй вэ? Харин Сатан үүнийг хийдэггүй. Тэр хүн төрөлхтнийг завхруулдаг; хүн төрөлхтнийг завхруулах ажлаа орчлон ертөнц даяар тасралтгүй явуулдаг. Мэдээж Бурхан ч бас ажлаа хийн, Сатанд ямар ч анхаарал хандуулдаггүй. Сатан хэчнээн их эрх мэдэлтэй байх нь хамаагүй, тэр эрх мэдлийг Бурхан л өгсөн; Бурхан үнэндээ Өөрийн бүх эрх мэдлийг үүнд ердөө өгөөгүй, тиймээс Сатан юу ч хийсэн бай, Бурханаас давж хэзээ ч чадахгүй ба үргэлж Бурханы атганд байх болно. Бурхан Өөрийн ямар ч үйл хэргийг тэнгэрт байхдаа илчлээгүй. Тэр ердөө л Сатанд багахан хэмжээний эрх мэдэл өгч, бусад тэнгэрэлчийг түүгээр хянуулсан. Тиймээс, Сатан юу ч хийлээ гэсэн, Бурханы эрх мэдлээс давж чадахгүй, учир нь анх Бурханы түүнд өгсөн эрх мэдэл хязгаарлагдмал юм. Бурхан ажиллаж байхад Сатан үймүүлдэг. Эцсийн өдрүүдэд түүний үймээн самуун дууссан байх болно; үүний нэгэн адил Бурханы ажил ч бас дуусаж, Бурханы бүрэн төгс болгохыг хүсдэг хүмүүс бүрэн төгс болгуулна. Бурхан хүмүүсийг эерэгээр чиглүүлдэг; Түүний амь бол хэмжээлшгүй агаад хязгааргүй амийн ус билээ. Сатан хүнийг тодорхой хэмжээнд завхруулсан; эцэст нь амийн амьд ус хүнийг бүрэн төгс болгоно, тэгээд Сатан хөндлөнгөөс оролцож, өөрийн ажлыг явуулах боломжгүй болно. Тийнхүү Бурхан энэ хүмүүсийг бүрэн олж авч чадна. Сатан одоо ч гэсэн үүнийг хүлээн авахаас татгалзсаар байгаа; тэр байнга Бурханы эсрэг сөрөн зогсдог ч Бурхан түүнд огт анхаарал хандуулдаггүй. “Би Сатаны бүх харанхуй хүчийг, үүний бүх харанхуй нөлөөг ялна” гэж Бурхан хэлсэн. Энэ нь махбодоор хийгдэх ажил бөгөөд энэ нь бас махбод болохын утга учир буюу эцсийн өдрүүдэд Сатаныг ялах ажлын үе шатыг дуусгаж, Сатанд харьяалагддаг бүх зүйлийг арчин хаях явдал юм. Бурхан Сатаныг ялах нь зайлшгүй! Үнэндээ Сатан аль хэдийн бүтэлгүйтсэн. Агуу улаан лууны газар нутаг даяар сайн мэдээ тархаж эхлэх үед, өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурхан ажлаа эхлүүлж, энэ ажлыг явуулж эхлэх үед Сатан бүрмөсөн ялагдсан, учир нь бие махбодтой болохын гол зорилго нь Сатаныг ялан дийлэхийн төлөө байсан билээ. Бурхан дахин нэг удаа махбод болж, ямар ч хүч зогсоож чадахгүй Өөрийн ажлыг хэрэгжүүлж эхлэхийг Сатан хармагцаа энэ ажлын бараанаар мэгдэн сандарч, цаашид гай тарьж зүрхлээгүй. Эхэндээ Сатан өөрт нь ч бас маш их мэргэн ухаан өгөгдсөн гэж бодсон ба Бурханы ажлыг үймүүлж, түйвээсэн; гэхдээ тэр, Бурхан

дахин нэг удаа махбод болж, Өөрийнхөө ажилд хүн төрөлхтний төлөөх илчлэл, шүүлт болгон Сатаны тэрслүү байдлыг ашиглаж, улмаар хүмүүсийг байлдан дагуулж, Сатаныг ялна гэж бодоогүй юм. Бурхан Сатанаас илүү ухаалаг бөгөөд Бурханы ажил түүнээс хамаагүй хол давдаг. Тиймээс өмнө нь Миний хэлж байсанчлан: “Миний хийдэг ажил Сатаны ов мэхний хариуд хэрэгждэг; эцэстээ Би Өөрийн төгс хүчийг болон Сатаны хүчин мөхөс байдлыг илчилнэ.” Бурхан урд талд нь Өөрийн ажлыг хийх үед Сатан араас нь дагах ба эцэстээ бүрмөсөн устгагдана—өөрийг нь юу цохисныг ч тэр мэдэхгүй! Аль хэдийн сүйрэн унаж, няцлуулмагцаа л тэр үнэнийг ухаарна, харин тэр үед аль хэдийн галт нууранд шатчихсан байх болно. Тэгэхэд Сатан бүрэн үнэмшихгүй гэж үү? Учир нь тэр үед түүнд ашиглах арга заль байхгүй байх болно!

Алхам алхмаар хийгддэг энэхүү бодит ажил Бурханы зүрх сэтгэлийг хүн төрөлхтний төлөөх уй гашууд үргэлж автуулдаг тул Сатантай хийсэн Түүний дайн зургаан мянган жилийн турш үргэлжилсэн бөгөөд Бурхан: “Би дахин хэзээ ч хүн төрөлхтнийг бүтээхгүй, тэнгэрэлчүүдэд ч дахин эрх мэдэл олгохгүй” гэж хэлсэн юм. Тэр үеэс эхлээд, тэнгэрэлчүүд газар дээр ажиллахаар ирэхдээ зарим нэг ажил хийхэд нь л Бурханыг дагаж байсан; Тэр тэдэнд дахин хэзээ ч эрх мэдэл өгөөгүй. Израильчуудын харсан тэнгэрэлчүүд ажлаа яаж хийж байсан бэ? Тэд хүмүүсийн зүүдэнд үзэгдэж, Еховагийн үгийг дамжуулж байсан. Есүс цовдлогдсоныхоо дараа гурав хоноод дахин амилах үед тэнгэрэлчүүд бул чулууг хажуу тийш түлхсэн; Бурханы Сүнс энэ ажлыг биечлэн хийгээгүй юм. Тэнгэрэлчүүд иймэрхүү ажил л хийж байсан; тэд туслах дүрд тоглосон боловч ямар ч эрх мэдэлгүй байсан, учир нь Бурхан тэдэнд дахин хэзээ ч эрх мэдэл олгохгүй. Хэсэг хугацаанд ажилласны дараа газар дээр Бурханы ашиглаж байсан хүмүүс Бурханы байр суурийг авч, “Би орчлон ертөнцийг даван гармаар байна! Би гурав дахь тэнгэрт зогсмоор байна! Бид бүрэн эрх мэдэлтэйгээр хаанчлахыг хүсэж байна!” гэж хэлсэн. Тэд хэдэн өдөр ажилласныхаа дараа биеэ тоосон; тэд газар дээр бүрэн эрх мэдэлтэй байж, өөр улс байгуулж, бүх зүйлийг хөлийнхөө дор байлгаж, гурав дахь тэнгэрт зогсохыг хүссэн. Чи ердөө л Бурханы ашигладаг хүн гэдгээ мэдэхгүй гэж үү? Чи яаж гурав дахь тэнгэр лүү гарч чадах юм бэ? Бурхан чимээгүйхнээр, хашхиралгүйгээр газар дээр ажиллахаар ирээд, ажлаа сэмхэн дуусгасныхаа дараа явж оддог. Тэр хэзээ ч хүмүүс шиг хашхирдаггүй, харин ч Өөрийн ажлыг бодитоор хэрэгжүүлдэг. Тэр сүмд ороод, “Би та нарыг бүгдийг арчин хаяна! Би та нарыг харааж, гэсгээнэ!” гэж хэзээ ч хашхирдаггүй. Тэр зүгээр л Өөрийн ажлыг үргэлжлүүлэн хийдэг ба хийж дуусмагцаа явдаг. Өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөж, индэр дээрээс бусдад зааж сургаж, урт сүржин илтгэл тавьж, бодит бус асуудлыг хэлэлцдэг шашны тэр пасторууд голдоо ортол биеэ тоосон байдаг! Тэд бол тэргүүн тэнгэрэлчийн үр удам билээ!

Зургаан мянган жилийн ажлаа өнөөдрийг хүртэл хийснийхээ дараа Бурхан олон үйл хэргээ аль хэдийн илчилсэн ба үүний гол зорилго нь Сатаныг ялж, бүх хүн төрөлхтөнд аврал авчрах явдал байлаа. Тэрээр энэ боломжийг ашиглан тэнгэрт

байгаа бүх зүйл, газар дээрх бүх зүйл, далай тэнгис дэх бүх зүйл болон газар дээрх Бурханы бүтээл нэг бүрд Өөрийн төгс хүчийг харуулж, Өөрийн бүх үйл хэргийг үзүүлдэг. Мөн Сатаныг ялах боломжийг шүүрэн авснаараа Тэр хүмүүст Өөрийн бүх үйл хэргийг илчилж, тэднээр Өөрийгөө магтуулж, Сатаныг ялсан мэргэн ухаанаа өргөмжлүүлдэг. Газар дээрх, тэнгэр дэх болон далай тэнгис доторх бүх зүйл Бурханд алдар сууг авчирч, Түүний төгс хүчийг магтаж, Түүний үйл хэрэг нэг бүрийг магтаж, Түүний ариун нэрийг хашхирна. Энэ нь Тэр Сатаныг ялсны нотолгоо; Сатаныг эрхэндээ оруулсны нотолгоо. Үүнээс ч чухал нь, хүн төрөлхтнийг аварсных нь нотолгоо юм. Бурханы бүх бүтээл Түүнд алдар суу авчран, дайснаа ялж, ялгууснаар буцан ирснийх нь төлөө Түүнийг магтах ба Түүнийг агуу ялгуусан Хаан хэмээн шагшин магтана. Түүний зорилго ердөө л Сатаныг ялах явдал биш, иймээс Түүний ажил зургаан мянган жилийн турш үргэлжилсэн юм. Тэр Сатаны ялагдлыг ашиглан хүн төрөлхтнийг авардаг; Сатаны ялагдлыг ашиглан Өөрийн бүх үйл хэрэг, бүх алдар сууг илчилдэг. Тэрээр алдаршина, үй түмэн тэнгэрэлч Түүний бүх алдрыг харна. Тэнгэр дэх зарлага элчүүд, газар дээрх хүмүүс болон газар дээрх бүх бүтээл Бүтээгчийн алдар сууг харна. Энэ бол Түүний хийдэг ажил юм. Тэнгэр дэх болон газар дээрх Түүний бүтээл бүгдээрээ Түүний алдар сууг харах бөгөөд Сатаныг бүрэн ялсныхаа дараа Тэр ялгууснаар эргэн ирж, хүн төрөлхтнөөр Өөрийгөө магтуулж, улмаар Өөрийнхөө ажилд давхар ялалт байгуулна. Эцэстээ бүх хүн төрөлхтнийг Тэр байлдан дагуулах ба эсэргүүцэж, тэрсэлдэг хэнийг ч арчин хаяна; өөрөөр хэлбэл, Сатанд харьяалагддаг бүх хүнийг Тэр арчин хаяна. Чи одоо Бурханы маш олон үйл хэргийг харж байгаа мөртөө мөн л эсэргүүцэн, тэрсэлдэг ба захирагддаггүй; чи дотроо олон зүйл өвөрлөж, хүссэн бүхнээ хийдэг. Чи өөрийн шунал тачаал, дур сонирхлыг дагадаг; энэ нь бүгд тэрслүү байдал, эсэргүүцэл юм. Махан биеийн төлөө, шунал тачаалынхаа төлөө, түүнчлэн дуртай зүйлс, дэлхий ертөнц, Сатаны төлөө Бурханд итгэх нь бузар заваан юм; энэ нь уг чанартаа эсэргүү, тэрслүү байдаг. Өнөө үед төрөл бүрийн итгэл байдаг: Зарим хүн гай гамшгаас хоргодох газар эрж хайдаг, бусад нь ерөөл хүртэхээр эрэлхийлдэг; зарим нь нууцуудыг ойлгохыг хүсдэг байхад бусад нь мөнгөний араас хөөцөлддөг. Эдгээр нь төрөл бүрийн эсэргүүцэл бөгөөд бүгд доромжлол юм! Хүн эсэргүүцэж, тэрсэлнэ гэдэг нь ийм үйлдлүүдийг хэлдэг бус уу? Өнөө үед олон хүн дургүйцэж, гомдоллож, шүүлт хийдэг. Энэ нь бүгд хорон муу санаатны хийдэг зүйл юм; тэдгээр нь хүний эсэргүүцэл, тэрслүү байдлын жишээ билээ. Тийм хүмүүс Сатанд эзэмдүүлж, эзлэгддэг. Бурханы олж авдаг хүмүүс бол Түүнд бүрэн захирагддаг хүмүүс; тэд Сатанаар завхруулагдсан ч Бурханы одоогийн ажлаар аврууллж, байлдан дагуулагдсан, гай зовлон туулж, эцэст нь Бурханаар бүрэн авхуулсан, цаашид Сатаны эзэмшил дор амьдрахаа больж, шударга бус байдлаас ангижирсан, ариун байдлыг амьдран харуулахыг хүсдэг хүмүүс юм—ийм хүмүүс бол хамгийн ариун хүмүүс; үнэхээр ариун хүмүүс юм. Хэрвээ чиний одоогийн үйлдлүүд Бурханы шаардлагын нэгээхэн хэсэгтэй ч тохирдоггүй бол чи таягдан хаягдана. Энэ нь маргаангүй. Бүх зүйл

өнөөдрийн хэрэг явдлаас хамаардаг; хэдийгээр чамайг урьдчилан тогтоож, сонгосон ч өнөөдрийн үйлдэл чинь төгсгөлийг чинь тодорхойлно. Хэрвээ чи одоо хөл нийлүүлж чадахгүй бол таягдан хаягдана. Хэрвээ одоо хөл нийлүүлж чадахгүй юм бол чи яаж дараа нь хөл нийлүүлж чадах юм бэ? Одоо чиний өмнө ийм агуу гайхамшиг гарч ирсэн ч чи мөн л итгэдэггүй. Бурхан Өөрийн ажлыг дуусгаад, цаашид дахин ийм ажил хийхгүй бол чи дараа нь яаж Түүнд итгэх юм бэ? Тэр үед чиний хувьд Түүнийг дагах бүр ч боломжгүй байх болно! Хожим нь Бурхан, бие махбодтой болсон Бурханы ажилд хандах хандлага, мэдлэг, туршлагад чинь тулгуурлан нүгэлтэй юу, зөв шударга уу гэдгийг чинь тодорхойлж, төгс болгуулах уу, эсвэл таягдан хаягдах уу гэдгийг чинь тодорхойлно. Чи одоо тодорхой харах ёстой. Ариун Сүнс ингэж ажилладаг: Чиний өнөөдрийн үйлдлийн дагуу Тэр төгсгөлийг чинь тодорхойлдог. Өнөөдрийн үгийг хэн хэлдэг вэ? Өнөөдрийн ажлыг хэн хийдэг вэ? Өнөөдөр таягдан хаягдах уу гэдгийг чинь хэн шийддэг вэ? Чамайг төгс болгохыг хэн шийддэг вэ? Энэ бүхнийг Би Өөрөө хийдэг бус уу? Би бол эдгээр үгийг хэлдэг Нэгэн; Би бол ийм ажлыг хийдэг Нэгэн. Хүмүүсийг харааж, гэсгээж, шүүх нь бүгд Миний ажлын хэсгүүд. Эцэст нь чамайг таягдан хаяхыг ч бас Би шийднэ. Энэ бүх зүйл Миний мэдэх хэрэг! Чамайг төгс болгох нь Миний хэрэг ба чамд ерөөл эдлүүлэх нь ч бас Миний мэдэх хэрэг юм. Энэ нь бүгдээрээ Миний хийдэг ажил. Чиний төгсгөлийг Ехова урьдчилан тогтоогоогүй; үүнийг өнөөдрийн Бурхан тогтоож байгаа. Энэ нь одоо тодорхойлогдож байгаа; харин дэлхий ертөнц бүтээгдэхээс ч өмнө тодорхойлогдоогүй. Зарим хөгийн хүмүүс: “Таны нүд нэг л болохгүй байх шиг байна, Та намайг харах ёстой байдлаараа харахгүй байна. Эцэстээ Сүнс яг юу илчлэхийг Та харах болно!” гэж хэлдэг. Есүс анх Иудасыг шавиа болгон сонгосон. “Өөрөөс нь урвах шавийг Тэр яаж сонгож чадав аа?” гэж хүмүүс асуудаг. Эхэндээ Иудаст Есүсээс урвах санаа байгаагүй; энэ нь ердөө дараа нь тохиолдсон. Тухайн үед Есүс Иудаст нэлээд таатай хандаж байсан; Тэр Иудасаар Өөрийгөө дагуулж, санхүүгийн асуудлаа түүнд хариуцуулсан. Иудас мөнгө завшихыг мэдэж байсан бол Есүс түүнд хэзээ ч тийм асуудал хариуцуулахгүй байсан юм. Энэ хүн шударга бус, зальхай, ах эгч нараа хуурна гэдгийг Есүс анх мэдээгүй гэж хэлж болно. Хожим нь, Иудас хэсэг хугацаанд Өөрийг нь дагасны дараа ах, эгч нараа аргалж, мөн Бурханыг аргалж байхыг нь Есүс харсан. Иудас мөнгөний хүүдийнээс мөнгө авдаг зуршилтай болохыг хүмүүс ч бас олж мэдээд, дараа нь Есүст энэ тухай хэлсэн. Тэр үед л Есүс юу болоод байгааг мэдсэн. Есүс цовдлолын ажлыг явуулах байсан, мөн Өөрөөс нь урвах хүн хэрэгтэй байсан ба Иудас энэ дүрд тоглоход яг тохирох хүн байж таарсан учраас л Есүс: “Бидний дундаас нэг нь Надаас урвана. Хүний Хүү энэхүү урвалтыг ашиглан цовдлогдоод, гурван өдрийн дараа дахин амилна” гэж хэлсэн юм. Тухайн үед Есүс үнэндээ Өөрөөс нь урвана гээд Иудасыг сонгосон юм биш; харин ч эсрэгээрээ Иудасыг үнэнч шавь нь байгаасай гэж Тэр хүссэн. Санаандгүйгээр Иудас Эзэнээс урвасан шунахай дорд амьтан байж таарсан тул Есүс энэ нөхцөл байдлыг ашиглан Иудасыг

энэхүү ажилд сонгожээ. Хэрвээ Есүсийн арван хоёр шавь бүгд үнэнч байж, тэдний дундаас нэг нь ч Иудас шиг байгаагүй бол Есүсээс урвах хүн нь эцэстээ шавь нараас нь өөр хүн байх байсан юм. Гэвч тухайн үед тэдний дунд хээл хахууль авах дуртай Иудас гэх нэгэн байж таарсан. Тиймээс Есүс ажлаа гүйцээхийн тулд энэ хүнийг ашигласан юм. Энэ хэчнээн энгийн байсан гээч! Есүс Өөрийнхөө ажлын эхэнд үүнийг урьдчилан тогтоогоогүй; харин бүх зүйл тодорхой цэгт хүртэл өрнөсний дараа л энэ шийдвэрийг гаргажээ. Энэ нь Есүсийн шийдвэр, өөрөөр хэлбэл Бурханы Сүнсний Өөрийн шийдвэр байлаа. Анх Есүс Иудасыг сонгосон; Иудас дараа нь Есүсээс урвасан бөгөөд энэ нь зорилгоо биелүүлэхийн тулд Ариун Сүнсний хийсэн зүйл байв. Энэ нь тухайн үед Ариун Сүнсний хийсэн ажил байсан юм. Есүс Иудасыг сонгох үедээ Өөрөөс нь урвана гэж огт мэдээгүй. Искариотын Иудас гэдгийг л мэдэж байсан. Та нарын төгсгөл ч гэсэн, өнөөдрийн дуулгавартай байдлын чинь түвшин болон амийн өсөлтийн түвшний чинь дагуу тодорхойлогддог болохоос дэлхий ертөнц бүтээгдэх үед та нарын төгсгөл урьдчилан тогтоогдсон гэх хүний үзлээр тодорхойлогддоггүй. Чи эдгээр зүйлийг тодорхой ухамсарлах ёстой. Энэ бүх ажил чиний төсөөлдөг шиг хийгддэггүй юм.

НЭРШИЛ БОЛОН ЯЛГАМЖ ЧАНАРЫН ТАЛААР

Хэрвээ чи Бурханаар ашиглагдахад тохирсон байхыг хүсвэл Бурханы ажлыг мэдэх ёстой, өмнө нь (Шинэ болон Хуучин Гэрээнд) Түүний хийсэн ажлыг мэдэх ёстой, түүнчлэн Түүний өнөөдрийн ажлыг мэдэх ёстой; өөрөөр хэлбэл, чи 6,000 жилийн турш хийгдсэн Бурханы ажлын гурван үе шатыг мэдэх ёстой. Хэрвээ чамаас сайн мэдээ түгээхийг хүсвэл Бурханы ажлыг мэдэхгүйгээр чи үүнийг хийж чадахгүй. Библи болон Хуучин Гэрээний талаар, мөн тухайн үеийн Есүсийн ажил болон үгийн талаар танай Бурхан юу хэлсэн тухай хэн нэгэн чамаас асууж магадгүй. Хэрвээ чи тэдэнд Библийн дотоод түүхийг ярьж чадахгүй бол тэд үнэмшихгүй. Эхэндээ Есүс Өөрийн шавь нарт Хуучин Гэрээний талаар маш ихийг ярьсан. Тэдний уншсан бүхэн нь Хуучин Гэрээнийх байсан; Шинэ Гэрээ нь Есүсийг цовдлогдсоноос хойш хэдэн арван жилийн дараа л бичигдсэн юм. Сайн мэдээ түгээхийн тулд та нар үндсэндээ Библийн дотоод үнэн, Израиль дахь Бурханы ажил буюу Еховагийн хийсэн ажлыг ойлгох ёстой, бас Есүсийн хийсэн ажлыг ойлгох учиртай. Эдгээр нь бүх хүний хамгийн их анхаардаг асуудлууд бөгөөд ажлын тэрхүү хоёр үе шатны дотоод түүх бол тэдний сонсоогүй зүйл юм. Сайн мэдээ түгээхдээ, өнөөдрийн Ариун Сүнсний ажлын тухай яриаг эхлээд хойш тавь. Ажлын энэ үе шат тэдний хувьд хүршгүй байдаг, учир нь та нарын эрэлхийлдэг зүйл бол хамгийн өндөр дээд зүйл—Бурханы тухай мэдлэг болон Ариун Сүнсний ажлын тухай мэдлэг бөгөөд энэ хоёроос илүү өндөр дээд зүйл гэж үгүй. Хэрвээ та нар эхлээд өндөр дээд зүйлийн талаар ярих юм бол энэ нь тэдний хувьд хэтэрхий

их байх болно, учир нь Ариун Сүнсний тийм ажлыг хэн ч туулж байгаагүй; энэ нь урьд өмнө тохиолдож байгаагүй ба хүн хүлээн зөвшөөрөхөд амархан биш байдаг. Тэдний туршлага нь Ариун Сүнсний зарим нэг тохиолдлын ажлыг агуулсан өнгөрсөн үеийн хуучин зүйл байдаг. Тэдний туулдаг зүйл нь өнөөдрийн Ариун Сүнсний ажил биш, эсвэл өнөөдрийн Бурханы хүсэл биш. Тэд ямар ч шинэ гэрэлгүйгээр, ямар ч шинэ зүйлгүйгээр хуучин ёс заншлын дагуу үйлдсээр байдаг.

Есүсийн эрин үед Ариун Сүнс Өөрийн ажлыг ихэвчлэн Есүсийн дотор хийсэн байхад сүмд тахилчийн өмсгөл өмсөн Еховад үйлчилж байсан хүмүүс гуйвшгүй үнэнчээр үүнийгээ хийсэн. Тэд ч бас Ариун Сүнсний ажилтай байсан боловч Бурханы өнөөгийн хүслийг ухаарах чадваргүй байсан ба хуучин хэрэгжүүлэлтийн дагуу зүгээр л Еховад үнэнч хэвээр үлдэж, шинэ удирдамжгүй байсан юм. Есүс ирж, шинэ ажил авчирсан атал сүмд үйлчилж байсан тэр хүмүүст шинэ удирдамж байгаагүй, шинэ ажил ч байгаагүй. Сүмд үйлчлэнгээ тэд зүгээр л хуучин хэрэгжүүлэлтийг баримталж байсан бөгөөд сүмийг орхихгүйгээр ямар ч шинэ оролттой болж чадахгүй байв. Есүс шинэ ажил авчирсан ба Өөрийн ажлыг хийхийн тулд сүм рүү яваагүй. Тэр гагцхүү сүмийн гадна Өөрийн ажлыг хийсэн, учир нь Бурханы ажлын цар хүрээ аль эрт өөрчлөгдсөн байлаа. Тэрээр сүм дотор ажиллаагүй ба тэнд Бурханд үйлчлэх үедээ хүн аливаа зүйлийг байгаагаар нь л байлгаж байсан бөгөөд ямар ч шинэ ажлыг бий болгож чадаагүй юм. Үүний адилаар, өнөөгийн шашны хүмүүс Библийг шүтсээр байдаг. Хэрвээ чи тэдэнд сайн мэдээ түгээвэл тэд Библийн үгийн аар саар хэсгийг чам руу чулуудаж, ихээхэн нотолгоо олж, чамайг сандраан, хэлэх үггүй болгоно; тэгээд тэд чамд хаяг зүүж, итгэл бишрэлдээ мунхаг юм байна гэж бодно. “Та нар Бурханы үг болох Библийг ч мэддэггүй, тэгээд Бурханд итгэдэг гэж яаж хэлж чадаж байна аа?” гэж тэд хэлнэ. Тэгээд чамайг дорд үзэж, “Та нарын итгэдэг Нэгэн чинь Бурхан юм бол яагаад Тэр та нарт Хуучин болон Шинэ Гэрээний талаар бүгдийг хэлээгүй юм бэ? Нэгэнт Тэр Өөрийн алдрыг Израилиас Зүүн зүгт аваачсан юм бол яагаад Израильд хийгдсэн ажлыг мэддэггүй юм бэ? Тэр яагаад Есүсийн ажлыг мэддэггүй юм бэ? Хэрвээ та нар мэдэхгүй бол Тэр та нарт хэлээгүй гэдгийг энэ нь нотолж байна; Тэр хоёр дахь удаа бие махбодтой болсон Есүс юм бол яагаад эдгээр зүйлийг мэддэггүй юм бэ? Есүс Еховагийн хийсэн ажлыг мэдэж байсан; Тэр яагаад мэддэггүй юм бэ?” хэмээн хэлнэ. Цаг нь ирэхэд тэд чамаас ийм асуултууд асууна. Тэдний тархи ийм зүйлсээр дүүрэн байдаг; тэд асуухгүй байж яаж чадах юм бэ? Энэ урсгал дотор байгаа хүмүүс Библид анхаарлаа төвлөрүүлдэггүй, учир нь та нар өнөөдөр Бурханы алхам алхмаар хийсэн ажилтай мөр зэрэгцэн явсан, алхам алхмаар хийгддэг энэ ажлыг өөрсдийн нүдээр харсан, ажлын гурван үе шатыг тодорхой харсан, иймээс Библийг доош тавьж, үүнийг судлахаа болих хэрэгтэй болсон. Гэхдээ тэд үүнийг судлахгүй байж чадахгүй, учир нь тэд алхам алхмаар хийгддэг энэ ажлын талаар огт мэддэггүй. Зарим хүн: “Бие махбодтой болсон Бурханы хийсэн ажил болон өнгөрсөн үеийн эш үзүүлэгчид, элч нарын хийсэн ажлын хоорондох ялгаа юу вэ?

Давидыг ч бас Эзэн гэж нэрлэдэг байсан, Есүс ч мөн адил; хэдийгээр тэдний хийсэн ажил ялгаатай байсан ч тэднийг адилхан нэрлэж байсан. Тэдний ялгамж чанар адилхан биш гэж яагаад хэлдэг юм бэ? Иоханы харсан зүйл үзэгдэл байсан, энэ нь ч бас Ариун Сүнснээс ирсэн бөгөөд Ариун Сүнсний хэлэх гэсэн үгийг тэр хэлж чадсан; тэгвэл яагаад Иоханы ялгамж чанар Есүсийнхээс өөр байсан юм бэ?" гэж асууна. Есүсийн хэлсэн үг Бурханыг бүрэн төлөөлж чаддаг байсан ба Бурханы ажлыг бүрэн төлөөлсөн. Иоханы харсан зүйл нь үзэгдэл байсан ба тэр Бурханы ажлыг бүрэн дүүрэн төлөөлөх чадваргүй байв. Иохан, Петр, Паул нар Есүсийн адилаар олон үг хэлсэн, гэхдээ тэд яагаад Есүстэй адил ялгамж чанартай байгаагүй юм бэ? Энэ нь үндсэндээ тэдний хийсэн ажил өөр байснаас болдог. Есүс Бурханы Сүнсийг төлөөлсөн ба шууд ажиллаж байсан Бурханы Сүнс байв. Тэрээр шинэ эрин үеийн ажил буюу өмнө нь хэний ч хийж байгаагүй ажлыг хийсэн юм. Тэрээр шинэ замыг нээж, Еховаг төлөөлж, Бурханыг Өөрийг нь төлөөлж байсан, харин Петр, Паул, Давид нарын хувьд хэн гэж дуудагдаж байснаас үл хамааран тэд зөвхөн Бурханы бүтээлийн ялгамж чанарыг л төлөөлж байсан ба Есүс юм уу Еховагаар илгээгдсэн байв. Иймээс тэд хэчнээн их ажил хийсэн ч, хэчнээн агуу гайхамшиг үзүүлсэн ч ердөө Бурханы бүтээлүүд байсан бөгөөд Бурханы Сүнсийг төлөөлөх чадваргүй байлаа. Тэд Бурханы нэрийн дор ажилласан, эсвэл Бурханаар илгээгдсэнийхээ дараа ажилласан; цаашлаад Есүс юм уу Еховагийн эхлүүлсэн эрин үед ажилласан бөгөөд өөр ямар ч ажил хийгээгүй. Эцсийн эцэст тэд ердөө л Бурханы бүтээлүүд байсан юм. Хуучин Гэрээнд олон эш үзүүлэгч зөгнөл хэлсэн, эсвэл зөгнөлийн ном бичсэн. Хэн ч тэднийг Бурхан гэж хэлээгүй боловч Есүсийг ажиллаж эхэлмэгц Бурханы Сүнс Түүнийг Бурхан гэж гэрчилсэн. Яагаад тэр вэ? Өдийд чи аль хэдийн мэдчихсэн байх ёстой! Урьд нь, элчүүд болон эш үзүүлэгчид олон янзын захидал бичиж, олон зөгнөл хэлсэн. Хожим нь хүмүүс тэдгээрийн заримыг Библид оруулахаар сонгосон ба зарим нь алга болсон. Тэдний хэлсэн бүхэн Ариун Сүнснээс ирсэн гэж хүмүүс хэлдэг байхад яагаад үүний заримыг сайн гэж үзээд, заримыг нь муу гэж үзсэн юм бэ? Яагаад заримыг нь сонгож, бусдыг нь сонгоогүй вэ? Хэрвээ тэдгээр нь үнэхээр Ариун Сүнсний хэлсэн үг байсан бол хүмүүс шилж сонгох хэрэгтэй байсан гэж үү? Есүсийн хэлсэн үг, хийсэн ажлын тухай тэмдэглэл яагаад Дөрвөн Сайн Мэдээ бүрд өөр байдаг вэ? Энэ нь тэдгээрийг тэмдэглэсэн хүмүүсийн алдаа биш гэж үү? Зарим хүн: "Паул болон Шинэ Гэрээний бусад зохиогчдын бичсэн захидлууд ба хийсэн ажил зарим талаар хүний хүслээс бий болж, хүний үзэлтэй холилдсон, тэгвэл Таны (Бурханы) өнөөдөр хэлж буй үгэнд ямар ч хүний хольц байхгүй гэж үү? Тэдгээр нь үнэхээр хүний ямар ч үзлийг агуулдаггүй юу?" хэмээн асууна. Бурханы хийдэг ажлын энэ үе шат нь Паул болон олон элч, эш үзүүлэгчийн хийснээс шал өөр юм. Ялгамж чанар нь ялгаатайгаар үл барам үндсэндээ хийсэн ажил нь ч ялгаатай байдаг. Паул цохигдож, Эзэний өмнө унасныхаа дараа ажиллахдаа Ариун Сүнсээр удирдуулсан бөгөөд илгээгдсэн нэгэн болсон юм. Иймээс тэр чуулгануудад захидал бичсэн бөгөөд эдгээр захидал нь

бүгд Есүсийн сургаалыг дагасан. Паул Эзэн Есүсийн нэрийн дор ажиллахаар Эзэнээр илгээгдсэн боловч Бурхан Өөрөө ирэхдээ ямар ч нэрийн дор ажиллаагүй ба Өөрийнхөө ажилд өөр хэнийг ч биш, харин Бурханы Сүнсийг төлөөлж байлаа. Бурхан Өөрийн ажлыг шууд хийхээр ирсэн: Түүнийг хүн төгс болгоогүй бөгөөд Түүний ажил ямар нэг хүний сургаалд тулгуурлан явагдаагүй. Ажлын энэ үе шатанд Бурхан хувийн туршлагаа ярьснаар удирдаагүй, харин ч Өөрт нь юу байгаагийн дагуу Өөрийн ажлыг шууд хэрэгжүүлсэн. Жишээлбэл, үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт, гэсгээлтийн цаг үе, үхлийн шалгалт, Бурханыг хайрлах цаг үе… Энэ бүх ажил урьд нь хэзээ ч хийгдэж байгаагүй бөгөөд хүний туршлага биш, харин өнөөгийн эрин үеийн ажил юм. Миний хэлсэн үгээс аль нь хүний туршлага вэ? Тэдгээр нь бүгд Сүнснээс шууд ирсэн, Сүнснээс гарсан бус уу? Чиний хэв чанар маш дорд учраас л чи үнэнийг нэвт харж чадахгүй байгаа юм! Миний ярьдаг амийн бодитой зам нь замыг залж чиглүүлэхийн төлөө байдаг бөгөөд өмнө нь хэн ч ярьж байгаагүй, урьд нь хэн ч энэ замыг туулж байгаагүй, хэн ч энэ бодит байдлыг мэдээгүй. Намайг эдгээр үгийг айлдахаас өмнө хэн ч, хэзээ ч үүнийг ярьж байгаагүй. Хэн ч, хэзээ ч ийм туршлагын талаар ярьж байгаагүй, мөн тэд хэзээ ч ийм нарийн ширийнийг яриагүй, түүнчлэн, эдгээр зүйлийг илчлэхийн тулд хэн ч, хэзээ ч тийм байдлыг зааж үзүүлээгүй. Өнөөдөр Миний хөтлөн явдаг энэ замаар хэн ч, хэзээ ч яваагүй ба хэрвээ хүн явж байсан бол энэ нь шинэ зам биш байх байсан юм. Паул, Петр хоёрыг жишээ болгон аваад үз. Есүсийг замаар анхлан явахаас өмнө тэдэнд хувийн туршлага гэж байгаагүй. Зөвхөн Есүсийг энэ замаар явсны дараа л тэд Есүсийн хэлсэн үг, явсан замыг туулсан; үүнээс тэд ихээхэн туршлага олж авч, захидлууд бичсэн. Иймээс хүний туршлага нь Бурханы ажилтай адилгүй бөгөөд Бурханы ажил нь хүний үзэл болон туршлагаар тодорхойлогддог мэдлэгтэй адилгүй. Өнөөдөр Би шинэ замаар явж, шинэ ажил хийж байгаа бөгөөд Миний ажил, айлдвар Иохан болон бусад бүх эш үзүүлэгчийнхээс өөр гэж Би ахин дахин хэлсэн. Би хэзээ ч эхэлж туршлага олж аваад, дараа нь үүнийгээ та нарт ярьж байгаагүй—хэзээ ч тэгж байгаагүй. Хэрвээ тэгсэн бол тэр нь та нарыг аль эрт удаашруулчих байсан биш үү? Урьд нь, олон хүний ярьдаг байсан мэдлэг өндөр байсан боловч тэдний бүх үг сүнслэг гэгддэг хүмүүсийн үгэнд л үндэслэдэг байсан. Тэд замыг залж чиглүүлээгүй, харин энэ нь тэдний туршлагаас, харсан зүйлээс нь, мэдлэгээс нь гарч ирсэн. Зарим нь тэдний үзэл байсан, зарим нь тэдний нэгтгэн дүгнэсэн туршлага байсан юм. Өнөөдөр Миний ажлын шинж чанар тэднийхээс шал өөр. Би бусдаар хөтлүүлэн явж үзээгүй, бас бусдаар төгс болгуулахыг ч хүлээн зөвшөөрөөгүй. Түүнчлэн, Миний ярьсан, нөхөрлөсөн бүхэн өөр хэнийхтэй ч адилгүй бөгөөд өөр хэн ч, хэзээ ч ярьж байгаагүй. Өнөөдөр та нар хэн бэ гэдгээс үл хамааран, та нарын ажил Миний хэлсэн үгийн үндсэн дээр хэрэгждэг. Эдгээр айлдвар болон ажилгүйгээр хэн эдгээр зүйлийг (үйлчлэл үзүүлэгчдийн шалгалт, гэсгээлтийн цаг үе…) туулах чадвартай байж, хэн тийм мэдлэгийн талаар ярьж чадах юм бэ? Чи үнэхээр үүнийг тодорхой харж чадахгүй юу? Ажлын үе шатаас үл

хамааран, Намайг үг хэлэнгүүт та нар Миний үгийн дагуу нөхөрлөж эхэлдэг ба тэдгээрийн дагуу ажилладаг, энэ нь та нарын хэний ч бодсон зам биш. Өдий хүрчхээд чи ийм энгийн, тодорхой асуултыг ойлгож чадахгүй байсаар л байна уу? Энэ нь хэн нэгний бодож олсон зам биш, мөн ямар нэг сүнслэг хүнийх дээр ч үндэслэсэн биш. Энэ нь шинэ зам бөгөөд нэгэнтээ Есүсийн хэлж байсан ихэнх үг ч хэрэглэгдэхээ больсон. Миний ярьдаг зүйл бол шинэ зууныг нээх ажил бөгөөд бие даасан ажил юм; Миний хийдэг ажил, хэлдэг үг бүгд шинэ. Энэ нь өнөөдрийн шинэ ажил биш гэж үү? Тухайн үед Есүсийн ажил ч бас ийм байсан. Түүний ажил ч бас сүм дэх хүмүүсийнхээс өөр байсан ба фарисайчуудын ажлаас ч ялгаатай байсан, мөн Израилийн бүх ард түмний хийсэнтэй огтхон ч адил төстэй байгаагүй. Үүнийг нүдээр харсныхаа дараа хүмүүс: “Үүнийг үнэхээр Бурхан хийсэн гэж үү?” гэцгээн шийдэж чадаагүй юм. Есүс Еховагийн хуулийг баримтлаагүй; хүнд зааж сургахаар ирэх үедээ Түүний хэлсэн бүхэн шинэ байсан бөгөөд эртний ариун хүмүүс, Хуучин Гэрээний эш үзүүлэгчдийн хэлснээс өөр байсан, үүнээс болоод хүмүүс эргэлзсэн хэвээр үлдсэн. Үүнээс үүдэн хүнтэй харьцахад маш төвөгтэй болсон юм. Ажлын энэ шинэ үе шатыг хүлээн зөвшөөрөхөөсөө өмнө та нарын дийлэнх нь тэрхүү сүнслэг хүмүүсийн суурин дээр хэрэгжүүлж, орох замаар алхсан. Гэхдээ өнөөдөр Миний хийдэг ажил асар их ялгаатай тул та нар энэ нь зөв үү, буруу юу гэдгийг шийдэж чаддаггүй. Урьд нь ямар замаар явсныг чинь Би тоодоггүй, мөн хэний “хоолыг” идсэнийг чинь, эсвэл хэнийг “эцгээ” болгосныг чинь ч сонирхдоггүй. Нэгэнт Би ирж, хүнийг залж чиглүүлэх шинэ ажлыг авчирсан учраас Намайг дагадаг бүхэн Миний хэлсний дагуу үйлдэх ёстой. Төрсөн “гэр бүл” чинь хэчнээн хүчирхэг байх нь хамаагүй чи Намайг дагах ёстой, хуучин хэрэгжүүлэлтийнхээ дагуу үйлдэх ёсгүй, чамайг “үрчилсэн эцэг” огцрох ёстой ба чи хүртэх ёстой ноогдол хувиа эрж хайхын тулд өөрийн Бурханы өмнө очих ёстой. Чи тэр чигтээ Миний гарт байгаа ба үрчилсэн эцэгтээ хэтэрхий сохроор итгэх ёсгүй; тэр чамайг бүрэн дүүрэн хянаж чадахгүй. Өнөөдрийн ажил бол бие даасан ажил. Өнөөдөр Миний хэлдэг бүхэн өнгөрсөн үеийн суурин дээр үндэслээгүй нь илэрхий; энэ нь шинэ эхлэл бөгөөд хэрвээ чи үүнийг хүний гараар бүтээгдсэн гэдэг бол аврагдахын аргагүй үнэхээр сохор хүн юм!

Исаиа, Езекиел, Мосе, Давид, Абрахам, Даниел нар Израилийн сонгогдсон хүмүүсийн дундах удирдагчид буюу эш үзүүлэгчид байсан. Яагаад тэднийг Бурхан гэж нэрлээгүй вэ? Яагаад Ариун Сүнс тэдэнд гэрчлэл хийгээгүй вэ? Есүсийг ажлаа эхэлж, үгээ хэлж эхлэнгүүт Ариун Сүнс яагаад Есүст гэрчлэл хийсэн бэ? Яагаад Ариун Сүнс бусдад нь гэрчлэл хийгээгүй вэ? Махан биетэй байсан тэр хүмүүсийг бүгдийг нь “Эзэн” гэж нэрлэж байсан. Тэднийг юу гэж нэрлэж байснаас үл хамааран тэдний ажил өөрсдийнх нь оршихуй, мөн чанарыг төлөөлж байсан ба оршихуй болон мөн чанар нь тэдний ялгамж чанарыг төлөөлж байв. Тэдний мөн чанар нь нэршилтэй нь хамаагүй байсан; харин тэдний илэрхийлж байсан зүйл болон амьдран харуулж байсан зүйл мөн чанарыг нь төлөөлдөг байв. Хуучин Гэрээнд

Эзэн гэж дуудуулах нь маш энгийн зүйл байсан ба хүнийг юу ч гэж дуудаж болно, гэхдээ түүний мөн чанар болон төрөлхийн ялгамж чанар нь хувиршгүй байсан. Тэрхүү хуурамч Христүүд, хуурамч эш үзүүлэгчид, хууран мэхлэгчдийн дунд “Бурхан” гэж дуудуулдаг хүмүүс ч бас байдаг бус уу? Тэгвэл яагаад тэд Бурхан биш вэ? Учир нь тэд Бурханы ажлыг хийх чадваргүй. Угтаа тэд бол хүн, хүмүүсийг мэхлэгчид болохоос Бурхан биш, иймээс тэдэнд Бурханы ялгамж чанар байдаггүй. Давид ч гэсэн арван хоёр овгийн дунд Эзэн гэж нэрлэгддэг байгаагүй гэж үү? Есүсийг ч бас Эзэн гэж нэрлэдэг байсан; яагаад Есүс ганцаараа бие махбодтой болсон Бурхан гэж нэрлэгдсэн бэ? Иеремиаг ч бас хүний Хүү гэдэг байсан бус уу? Есүсийг ч гэсэн хүний Хүү хэмээн нэрлээгүй гэж үү? Яагаад Есүс Бурханы өмнөөс цовдлогдсон бэ? Түүний мөн чанар өөр байснаас болоогүй гэж үү? Түүний хийсэн ажил өөр байснаас болоогүй гэж үү? Алдар цол хамаатай гэж үү? Хэдийгээр Есүсийг ч бас хүний Хүү гэж нэрлэж байсан боловч Тэр бол анх удаа бие махбодтой болсон Бурхан байсан, Тэрээр эрх мэдэл эзэмшиж, золин авралын ажлыг гүйцэтгэхийн тулд ирсэн. Есүсийн ялгамж чанар, мөн чанар нь хүний Хүү хэмээн нэрлэгдэж байсан бусад хүмүүсийнхээс өөр байсан гэдгийг энэ нь нотолдог. Ариун Сүнсний ашиглаж байсан хүмүүсийн хэлсэн бүх үг Ариун Сүнснээс ирсэн гэж өнөөдөр та нараас хэн чинь хэлж зүрхлэх вэ? Тийм зүйл хэлж зүрхлэх хүн байна уу? Хэрвээ чи тийм зүйл хэлдэг бол яагаад Езрагийн зөгнөлийн ном хаягдсан бэ, мөн яагаад эртний ариун хүмүүс болон эш үзүүлэгчдийн номуудад ч мөн адил зүйл тохиолдсон бэ? Хэрвээ тэдгээр нь бүгд Ариун Сүнснээс ирсэн юм бол яагаад та нар тийм дурааараа сонголт хийж зүрхэлдэг юм бэ? Чи Ариун Сүнсний ажлыг сонгох эрхтэй юу? Израилийн олон түүх мөн хаягдсан. Хэрвээ чи өнгөрсөн үеийн энэ бүх бичвэр Ариун Сүнснээс ирсэн гэж итгэдэг юм бол яагаад зарим ном хаягдсан бэ? Хэрвээ тэдгээр нь бүгд Ариун Сүнснээс ирсэн бол бүгдийг нь хадгалж, чуулгануудын ах, эгч нарт уншуулахын тулд илгээх ёстой байсан. Тэдгээрийг хүний хүслээр сонгож, эсвэл хаях ёсгүй; тэгэх нь буруу юм. Паул, Иохан нарын туршлага хувийн хэрсүү ухаантай нь холилдсон гэж хэлдэг нь тэдний туршлага болон мэдлэг Сатанаас ирсэн гэсэн үг биш, харин тэдэнд өөрсдийнх нь туршлага, хэрсүү ухаанаас гарсан зүйл байсан л гэсэн үг юм. Тэдний мэдлэг тухайн үеийн бодит туршлагынх нь дагуу байсан ба энэ бүхэн нь Ариун Сүнснээс ирсэн гэдгийг хэн итгэлтэйгээр хэлж зүрхлэх юм бэ? Хэрвээ Дөрвөн Сайн Мэдээ нь бүгд Ариун Сүнснээс ирсэн юм бол яагаад Матай, Марк, Лук, Иохан нар дор бүрнээ Есүсийн ажлын талаар өөр өөр зүйл хэлсэн юм бэ? Хэрвээ та нар үүнд итгэхгүй бол Петр Эзэнийг гурван удаа үгүйсгэсэн тухай Библийн тэмдэглэлийг аваад үз: Тэдгээр нь бүгд өөр бөгөөд тус бүрдээ өөрсдийн гэсэн онцлог шинжтэй байдаг. Олон мунхаг хүн: “Бие махбодтой болсон Бурхан ч бас хүн, иймээс Түүний хэлдэг үг бүхэлдээ Ариун Сүнснээс ирж чадах уу? Хэрвээ Паул, Иохан хоёрын үг хүний хүсэлтэй холилдсон байсан юм бол Түүний хэлдэг үг үнэхээр хүний хүсэлтэй холилдоогүй гэж үү?” хэмээн асуудаг. Ийм зүйл хэлдэг хүмүүс харалган бөгөөд мэдлэггүй юм!

Дөрвөн Сайн Мэдээг анхааралтай уншаад үз; Есүсийн хийсэн зүйл, хэлсэн үгийн талаар юу бичсэнийг унш. Тэмдэглэл бүр нь нэлээд өөр байдаг ба тус бүрдээ өөрсдийн гэсэн харах өнцөгтэй байдаг. Хэрвээ эдгээр номын зохиогчдын бичсэн зүйл бүгд Ариун Сүнснээс ирсэн бол бүгд адилхан, нэг янз байх ёстой байлаа. Тэгвэл яагаад ялгаатай байдаг вэ? Хүн үүнийг тодорхой харж чадахгүй бол туйлын мунхаг биш гэж үү? Хэрвээ чамаас Бурханд гэрчлэл хийхийг хүсвэл чи ямар гэрчлэл хийж чадах вэ? Бурханыг тийм байдлаар мэдэх нь Бурханд гэрчлэл хийж чадах уу? Хэрвээ бусад хүмүүс чамаас, “Иохан, Лук нарын тэмдэглэл хүний хүсэлтэй холилдсон юм бол та нарын Бурханы хэлсэн үг хүний хүсэлтэй холилдоогүй гэж үү?” хэмээн асуувал чи тодорхой хариулт өгч чадах уу? Лук, Матай нар Есүсийн үгийг сонсож, Есүсийн ажлыг харсныхаа дараа өөрсдийн мэдлэгийн тухай ярьж, Есүсийн хийсэн ажлын тухай зарим баримтыг дурсамж маягаар тоочсон. Тэдний мэдлэг бүхэлдээ Ариун Сүнсээр илчлэгдсэн гэж чи хэлж чадах уу? Библиэс гадна, тэднээс илүү өндөр мэдлэгтэй олон сүнслэг хүн байсан; яагаад тэдний үгийг дараагийн үеийнхэн нь авч үзээгүй вэ? Тэд ч бас Ариун Сүнсээр ашиглагдаагүй гэж үү? Өнөөдрийн ажилд Би Есүсийн ажлын сууринд үндэслэн Өөрийн хэрсүү ухааныг яриагүй, мөн Есүсийн ажлын цаад шалтгаантай харьцуулан Өөрийн хувийн мэдлэгийг ч яриагүй гэдгийг мэдэж ав. Есүс тухайн үед ямар ажил хийсэн бэ? Тэгвэл Би өнөөдөр ямар ажил хийж байгаа вэ? Миний хийж, хэлж байгаа зүйл урьд өмнө нь тохиолдож байгаагүй. Өнөөдөр Миний алхдаг замаар өмнө нь хэзээ ч хүн явж байгаагүй, өнгөрсөн эрин үеийн хүмүүс хэзээ ч алхаж байгаагүй. Өнөөдөр энэ нь нээгдсэн ба энэ нь Сүнсний ажил биш гэж үү? Хэдийгээр Ариун Сүнсний ажил байсан ч гэсэн, өнгөрсөн үеийн удирдагчид бүгдээрээ бусдын тавьсан суурин дээр өөрсдийн ажлыг явуулсан; гэхдээ Бурханы Өөрийн ажил бол өөр. Есүсийн ажлын үе шат ч бас адилхан байсан: Тэрээр шинэ замыг нээсэн юм. Тэр ирэхдээ тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг тунхаглаж, хүн гэмшиж, нүглээ улайх ёстой гэж хэлсэн билээ. Есүс Өөрийн ажлыг дуусгасны дараа Петр, Паул болон бусад хүмүүс Есүсийн ажлыг үргэлжлүүлж эхэлжээ. Есүс загалмайд цовдлогдож, тэнгэр өөд гарсны дараа цовдлолын замыг түгээхийн тулд Сүнс тэднийг илгээсэн. Хэдийгээр Паулын үг өндөр дээд байсан ч тэвчээр, хайр, зовлон, толгойгоо бүтээх, баптисм хүртэх, эсвэл дагах ёстой бусад сургаал гэх мэт Есүсийн хэлсэн зүйлийн суурин дээр үндэслэж байв. Энэ бүхнийг Есүсийн хэлсэн үгэнд суурилан хэлсэн юм. Тэд шинэ зам нээж чадаагүй, учир нь тэд бүгдээрээ Бурханы ашиглаж байсан хүмүүс юм.

Тухайн үеийн Есүсийн айлдвар болон ажил хоосон сургаал баримтлаагүй ба Тэрээр Хуучин Гэрээний хуулийн ажлын дагуу Өөрийн ажлыг гүйцэтгээгүй. Энэ нь Нигүүлслийн эрин үед хийгдэх ёстой ажлын дагуу хийгдсэн юм. Тэрээр Өөрийн авчирсан ажлын дагуу, Өөрийн хувийн төлөвлөгөөний дагуу, мөн Өөрийн үйлчлэлийн дагуу хөдөлмөрлөсөн; Тэр Хуучин Гэрээний хуулийн дагуу ажиллаагүй. Түүний хийсэн юу ч Хуучин Гэрээний хуулийн дагуу байгаагүй ба Тэрээр эш

үзүүлэгчдийн үгийг биелүүлэхийн тулд ажиллахаар ирээгүй. Бурханы ажлын үе шат болгон нь эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг биелүүлэх зорилгоор хийгддэггүй бөгөөд Тэр хоосон сургаалыг мөрдөхийн тулд, эсвэл эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг зориуд биелүүлэхийн тулд ирээгүй. Гэсэн ч Түүний үйлдэл эртний эш үзүүлэгчдийн зөгнөлийг нураагаагүй, өмнө нь Түүний хийсэн ажилд ч саад учруулаагүй. Түүний ажлын өвөрмөц шинж нь ямар ч сургаал мөрдөхгүйгээр Өөрийн хийх ёстой ажлыг хийх явдал байв. Тэр эш үзүүлэгч, эсвэл зөнч байгаагүй, харин Өөрийн хийх ёстой ажлыг бодитоор хийхээр ирсэн гүйцэтгэгч байсан бөгөөд Өөрийн шинэ эрин үеийг нээж, шинэ ажлыг хэрэгжүүлэхээр ирсэн юм. Мэдээж Есүс Өөрийн ажлыг хийхээр ирэхдээ Хуучин Гэрээний эртний эш үзүүлэгчдийн хэлсэн олон үгийг ч бас биелүүлсэн. Мөн өнөөдрийн ажил ч гэсэн Хуучин Гэрээний эртний эш үзүүлэгчдийн зөгнөлүүдийг биелүүлсэн. Би зүгээр л “хуучин хуанлийг” барихаа больсон төдий, тэгээд л тэр. Учир нь Миний хийх ёстой ажил илүү их байгаа, Миний та нарт хэлэх ёстой үг олон байгаа, энэхүү ажил болон үг Библийн эшлэлүүдийг тайлбарлахаас хавьгүй илүү ач холбогдолтой, яагаад гэвэл, тиймэрхүү ажил та нарт ямар ч ач холбогдолгүй, үнэ цэнгүй бөгөөд та нарт тусалж, эсвэл та нарыг өөрчилж чадахгүй. Би шинэ ажил хийхээр зорьсон болохоос Библийн ямар нэг эшлэлийг биелүүлэх гээгүй. Хэрвээ Бурхан Библийн эртний эш үзүүлэгчдийн үгийг биелүүлэхийн тулд л газар дэлхий дээр ирсэн бол бие махбодтой болсон Бурхан болон тэдгээр эртний эш үзүүлэгчийн хэн нь илүү агуу байх вэ? Эцсийн эцэст эртний эш үзүүлэгчид Бурханыг захирдаг уу, эсвэл Бурхан эртний эш үзүүлэгчдийг захирдаг уу? Чи эдгээр үгийг хэрхэн тайлбарлах вэ?

Эхэндээ Есүс Өөрийн үйлчлэлийг хараахан албан ёсоор эхлээгүй байх үедээ Өөрийг нь дагаж байсан шавь нарын адилаар заримдаа сүмд цуглаанд оролцож, магтан дуу дуулж, магтаал өргөж, Хуучин Гэрээг уншдаг байлаа. Тэр баптисм хүртээд боссоны дараа Сүнс албан ёсоор Түүн дээр буун ирж, ажиллаж эхлэн, Түүний ялгамж чанар болон хийх гэж байсан үйлчлэлийг нь илчилсэн юм. Үүнээс өмнө хэн ч Түүний ялгамж чанарыг мэдээгүй ба Мариагаас гадна Иохан ч мэдээгүй. Баптисм хүртэх үедээ Есүс 29 настай байлаа. Түүний баптисм дууссаны дараа тэнгэр нээгдэж: “Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг” гэх дуун гарчээ. Есүсийг баптисм хүртэнгүүт Ариун Сүнс ийм маягаар Түүнд гэрчлэл хийж эхэлсэн юм. 29 насандаа баптисм хүртэхээс өмнө Есүс хэвийн хүний амьдралаар амьдарч, идэх ёстойгоо идэж, хэвийн байдлаар унтаж, хувцасласан бөгөөд Түүний юу ч бусдаас ялгаатай байгаагүй, гэхдээ мэдээж зөвхөн хүний махан биеийн нүдээр л ийм байсан. Нас ахихын хэрээр Түүний оюун ухаан нэмэгдсэн гэж Библид бичсэн байдагчлан заримдаа Тэр бас сул дорой байсан, заримдаа бас аливааг тодорхой ялган таньж чаддаггүй байсан. Эдгээр үг нь, Тэр эгэл жирийн, хэвийн хүн чанартай байсан бөгөөд ялангуяа бусад хэвийн хүмүүсээс өөр байгаагүй гэдгийг л харуулж байгаа юм. Тэр ч бас хэвийн хүн шиг өсөж торнисон ба Түүнд онцгой зүйл юу ч байгаагүй. Гэсэн ч Тэр Бурханы халамж, хамгаалалт дор байлаа. Баптисм

хүртсэнийхээ дараа Тэр соригдож эхэлсэн, үүний дараа Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж, ажиллаж эхэлсэн ба хүч чадал, мэргэн ухаан, эрх мэдэл эзэмшсэн байлаа. Энэ нь, Түүнийг баптисм хүртэхээс өмнө Ариун Сүнс Түүн дотор ажиллаагүй, эсвэл Түүний дотор байгаагүй гэсэн үг биш. Түүнийг баптисм хүртэхээс өмнө ч гэсэн Ариун Сүнс дотор нь оршиж байсан боловч албан ёсоор ажиллаж эхлээгүй байв, учир нь Бурхан Өөрийн ажлыг хийх үед цаг хугацааны хязгаар байдаг, түүнчлэн хэвийн хүмүүст хэвийн өсөлтийн үйл явц байдаг. Ариун Сүнс үргэлж Түүний дотор амьдарсан. Есүс төрөх үедээ бусдаас өөр байсан ба үүрийн цолмон гарч ирсэн; Түүнийг төрөхөөс өмнө тэнгэрэлч Иосефийн зүүдэнд ирж, Мариа хүү төрүүлэх бөгөөд тэр хүүхэд Ариун Сүнснээс олдсон тухай түүнд хэлжээ. Есүсийг баптисм хүртсэний дараа Ариун Сүнс ажлаа эхэлсэн боловч Ариун Сүнс Есүс дээр дөнгөж л бууж ирсэн гэсэн үг биш юм. Ариун Сүнс Түүн дээр тагтаа мэт бууж ирсэн гэж хэлсэн нь Түүний үйлчлэл албан ёсоор эхэлснийг хэлж байгаа юм. Бурханы Сүнс Түүн дотор өмнө нь байсан боловч цаг нь болоогүй байсан учраас хараахан ажиллаж эхлээгүй байсан бөгөөд Сүнс ажлаа яаран эхлээгүй юм. Баптисмаар дамжуулан Сүнс Түүнд гэрчлэл хийсэн. Түүнийг уснаас гарч ирэх үед Сүнс Түүн дэх ажлаа албан ёсоор эхэлсэн ба Бурханы махбод болсон бие үйлчлэлээ хэрэгжүүлж эхэлсэн, мөн золин авралын ажлыг эхлүүлсэн гэдгийг энэ нь илтгэсэн, өөрөөр хэлбэл, Нигүүлслийн эрин үе албан ёсоор эхэлсэн юм. Иймээс Бурхан ямар ажил хийх нь хамаагүй Бурханы ажилд тодорхой цаг байдаг. Баптисм хүртсэний дараа Есүст ямар нэг тодорхой өөрчлөлт гараагүй; Тэр Өөрийн анхны махбодод л байсан. Тэр зүгээр л Өөрийн ажлыг эхэлж, Өөрийн ялгамж чанарыг илчилсэн ба эрх мэдэл, хүч чадлаар дүүрэн байсан билээ. Энэ талаараа Тэр өмнөхөөсөө өөр байсан юм. Түүний ялгамж чанар өөр байсан, өөрөөр хэлбэл, Түүний байр сууринд илт өөрчлөлт гарсан; энэ нь Ариун Сүнсний гэрчлэл байсан бөгөөд хүний хийсэн ажил биш байлаа. Эхэндээ хүмүүс мэдээгүй бөгөөд Ариун Сүнс тийм маягаар Есүсийг гэрчлэнгүүт бага зэрэг мэдэж авчээ. Хэрвээ Ариун Сүнс Өөрийг нь гэрчлэхээс өмнө Есүс агуу ажил хийчихсэн боловч Бурханы Өөрийн гэрчлэлгүй байсан бол Түүний ажил хэчнээн агуу байх нь хамаагүй хүмүүс хэзээ ч Түүний ялгамж чанарыг мэдэхгүй байх байв, учир нь хүний нүд үүнийг харж чадахгүй байх байсан юм. Ариун Сүнсний гэрчлэлийн үе шатгүйгээр хэн ч Түүнийг бие махбодтой болсон Бурхан хэмээн танихгүй байх байв. Ариун Сүнс Өөрийг нь гэрчилсний дараа Есүс өмнөхтэйгээ адилаар, ямар ч ялгаагүйгээр үргэлжлүүлэн ажилласан бол энэ нь үр нөлөө үзүүлэхгүй байх байсан бөгөөд энэ нь үндсэндээ Ариун Сүнсний ажлыг ч бас харуулдаг. Гэрчлэл хийснийхээ дараа Ариун Сүнс Өөрийгөө харуулах хэрэгтэй болсон, ингэснээр Тэр бол Бурхан бөгөөд Түүн дотор Бурханы Сүнс байгаа гэдгийг чи тодорхой харж чадах байв; Бурханы гэрчлэл буруу байгаагүй ба Түүний гэрчлэл зөв байсныг энэ нь нотолж чадах байлаа. Хэрвээ Ариун Сүнсний гэрчлэлийн өмнөх болон дараа Түүний ажил адилхан байсан бол бие махбодтой болсон Бурханы үйлчлэл болон Ариун Сүнсний ажлыг тодотгохгүй

байх байв, улмаар ямар ч тодорхой ялгаа байхгүй байх учраас хүн Ариун Сүнсний ажлыг таньж чадахгүй байх байсан юм. Гэрчлэл хийснийхээ дараа Ариун Сүнс энэ гэрчлэлээ хадгалах хэрэгтэй байсан тул Өөрийн мэргэн ухаан, эрх мэдлийг Есүст илэрхийлэх хэрэгтэй болсон ба энэ нь өнгөрсөн үеүдийнхээс өөр байлаа. Мэдээж энэ нь баптисмын үр дүн байгаагүй, баптисм бол ердөө ёслол төдий бөгөөд баптисм нь Түүний үйлчлэлээ хэрэгжүүлэх цаг болсныг харуулах арга зам байсан юм. Тийм ажил нь Бурханы агуу хүч чадлыг ил болгож, Ариун Сүнсний гэрчлэлийг ил болгохын төлөө байсан ба Ариун Сүнс энэ гэрчлэлээ эцсийг нь хүртэл хариуцах байв. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээс өмнө Есүс бас олон янзын газарт номлол сонсож, номлол хийж, сайн мэдээ түгээсэн. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх цаг нь хараахан болоогүй байсан учраас, бас Бурхан Өөрөө даруухнаар махбодод нуугдаж байсан учраас Тэр ямар нэгэн агуу ажил хийгээгүй бөгөөд цаг нь болох хүртэл ямар ч ажил хийгээгүй юм. Тэрээр хоёр шалтгааны улмаас баптисмаас өмнө ажил хийгээгүй: Нэгдүгээрт, Ариун Сүнс ажиллахын тулд Түүн дээр албан ёсоор бууж ирээгүй байсан (өөрөөр хэлбэл, тийм ажил хийх хүч чадал, эрх мэдлийг Ариун Сүнс Есүст хайрлаагүй байсан) учраас хэдий Өөрийн ялгамж чанарыг мэдэж байсан ч Есүс дараа хийхээр төлөвлөж байсан ажлаа хийж чадаагүй бөгөөд баптисм хүртэх өдрөө хүртэл хүлээх ёстой болсон юм. Энэ нь Бурханы цаг хугацаа бөгөөд хэн ч, бүр Есүс Өөрөө ч үүнийг зөрчиж чадаагүй; Есүс Өөрөө Өөрийнхөө ажилд саад учруулж чадаагүй. Мэдээж энэ нь Бурханы даруу байдал, түүнчлэн Бурханы ажлын хууль байсан; хэрвээ Бурханы Сүнс ажиллахгүй бол хэн ч Түүний ажлыг хийж чадахгүй. Хоёрдугаарт, Тэр баптисм хүртэхээсээ өмнө зүгээр л маш эгэл, жирийн хүн байсан бөгөөд бусад хэвийн, энгийн хүмүүсээс ямар ч ялгаагүй байсан; энэ нь бие махбодтой болсон Бурхан ер бусын байгаагүйн нэг тал юм. Бие махбодтой болсон Бурхан нь Бурханы Сүнсний зохицуулалтыг зөрчөөгүй; Тэр дэг журамтай байдлаар, маш хэвийн байдлаар ажилласан. Зөвхөн баптисмын дараа л Түүний ажил эрх мэдэл, хүч чадалтай болсон юм. Өөрөөр хэлбэл, хэдийгээр Тэр бие махбодтой болсон Бурхан байсан боловч ямар ч ер бусын үйлс хийгээгүй бөгөөд бусад хэвийн хүмүүсийн адилаар өссөн. Хэрвээ Есүс Өөрийн ялгамж чанарыг аль хэдийн мэдэж, баптисм хүртэхээсээ өмнө хаа сайгүй агуу ажил хийж, хэвийн хүмүүсээс өөр байж, ер бусын гэдгээ харуулсан бол Иохан ажлаа хийх боломжгүй байгаад зогсохгүй Бурханы хувьд ч гэсэн Өөрийн ажлын дараагийн алхмыг эхлэх аргагүй байх байлаа. Тэгсэн бол Бурханы хийсэн зүйл буруудсаныг энэ нь нотлох байсан бөгөөд Бурханы Сүнс болон Бурханы махбод болсон бие нэг эх сурвалжаас ирээгүй гэж хүнд харагдах байв. Иймд Библид бичигдсэн Есүсийн ажил нь баптисм хүртсэнийхээ дараа Түүний хийсэн ажил буюу гурван жилийн хугацаанд хийсэн ажил байв. Баптисм хүртэхээс өмнө Түүний хийсэн зүйлийг Библид тэмдэглээгүй байдаг, учир нь Тэр баптисм хүртэхээсээ өмнө энэ ажлыг хийгээгүй. Тэр ердөө эгэл хүн байсан ба эгэл хүнийг төлөөлж байлаа; Есүс Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэхээс өмнө хэвийн хүмүүсээс ямар ч ялгаагүй байсан бөгөөд

бусад хүмүүс Түүнээс ямар ч ялгаа олж харж чадаагүй. 29 настай болсныхоо дараа л Бурханы ажлын нэг үе шатыг гүйцэлдүүлэхээр ирсэн гэдгээ Есүс мэдсэн; өмнө нь Тэр Өөрөө мэдээгүй, учир нь Бурханы хийсэн ажил ер бусын байгаагүй юм. Тэр арван хоёр настайдаа синагогын цуглаанд оролцох үед Мариа Түүнийг хайж байсан бөгөөд Тэр бусад хүүхдийн адилаар нэг л өгүүлбэр хэлсэн: “Ээж ээ! Би Өөрийн Эцэгийн хүслийг юунаас ч илүү дээгүүрт тавих ёстойг та мэдэхгүй гэж үү?” Мэдээж Ариун Сүнснээс олдсон болохоор Есүс зарим талаар онцгой байж чадаагүй гэж үү? Гэхдээ Түүний онцгой байдал нь Тэр ер бусын байсан гэсэн утгатай биш, харин Тэр өөр ямар ч жаахан хүүхдүүдээс илүүгээр Бурханыг хайрлаж байсан гэсэн үг юм. Хэдийгээр Тэр хүний төрхтэй байсан боловч мөн чанар нь онцгой, бусдаас өөр байлаа. Харин баптисм хүртсэнийхээ дараа л Тэр Ариун Сүнс Өөрийнх нь дотор ажиллаж байгааг үнэхээр мэдэрч, Бурхан Өөрөө гэдгээ мэдэрчээ. Тэр 33 настай болох үедээ л Ариун Сүнс Өөрөөр нь дамжуулан цовдлолын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн гэдгийг үнэхээр ухаарсан юм. 32 настайдаа Тэр зарим дотоод үнэнийг мэдэж авсан, яг л Матайн Сайн Мэдээнд бичсэн байдагчлан: “Симон Петр, ‘Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн’ гэв” (Матай 16:16), “Тэр цагаас эхлэн Есүс Иерусалим руу хэрхэн явах ёстойгоо, ахлагчид, ахлах тахилч нар, хуулийн багш нараас их зовлон амсаж, алуулж, гурав дахь өдөр нь амилах зэргээ шавь нартаа хэлэв” (Матай 16:21). Тэр ямар ажил хийх ёстойгоо урьд нь мэддэггүй байсан боловч тодорхой цаг хугацаанд мэдсэн. Тэр төрөнгүүтээ тэрийг бүрэн мэдэж байсан юм биш; Ариун Сүнс Түүн дотор аажмаар ажилласан ба ажил нь тодорхой үйл явцтай байсан. Хэрвээ бүр эхнээсээ л Тэр бол Бурхан, Христ, бие махбодтой болсон хүний Хүү бөгөөд цовдлолын ажлыг гүйцэлдүүлэх ёстой гэдгээ мэдэж байсан бол яагаад Тэр өмнө нь ажиллаагүй юм бэ? Яагаад шавь нартаа Өөрийн үйлчлэлийн талаар хэлснийхээ дараа л Есүс уй гашууг мэдэрч, үүний төлөө үнэн сэтгэлээсээ залбирсан юм бэ? Яагаад Иохан Түүний замыг нээж, Түүнд баптисм хүртээсний дараа л Тэр өмнө нь ойлгоогүй байсан олон зүйлээ ойлгосон юм бэ? Энэ бол бие махбодтой болсон Бурханы ажил байсан гэдгийг энэ нь нотолдог ба иймээс Түүний хувьд ойлгож, биелүүлэх үйл явц гэж байсан, учир нь Тэр бол Бурханы махбод болсон бие байсан бөгөөд Түүний ажил Сүнсний шууд хийсэн ажлаас өөр байв.

Бурханы ажлын алхам бүр ав адилхан урсгалыг дагадаг, иймээс дэлхий бүтээгдсэн цаг үеэс эхлээд өнөөдрийг хүртэл Бурханы 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөний алхам бүрийг дараагийнх нь нягт дагадаг. Хэрвээ зам засах хэн ч байгаагүй бол араас нь явах хэн ч байхгүй байх байв; араас нь явдаг хүмүүс байгаа болохоор зам засдаг хүмүүс бас байгаа юм. Ийм маягаар тус ажил алхам алхмаар уламжлагдаж ирсэн. Нэг алхам нь нөгөөгөө дагадаг ба замыг нээх хүн үгүй бол ажлыг эхлүүлэх боломжгүй бөгөөд Бурхан Өөрийн ажлыг урагшлуулах аргагүй байх байлаа. Ямар ч алхам нөгөөтэйгээ зөрчилддөггүй ба урсгал үүсгэх дараллаар нэг нь нөгөөгөө дагадаг; үүнийг бүгдийг нь нэг Сүнс хийдэг. Гэхдээ хүн замыг нээж

байна уу, эсвэл үргэлжлүүлж байна уу гэдгээс үл хамааран, энэ нь тэдний ялгамж чанарыг тодорхойлдоггүй. Тийм биш гэж үү? Иохан замыг нээж, Есүс ажлыг нь үргэлжлүүлсэн, иймд Есүсийн ялгамж чанар Иоханыхаас дор байсан гэдгийг энэ нь нотолдог уу? Есүсээс өмнө Ехова Өөрийн ажлыг хэрэгжүүлсэн, иймээс Ехова бол Есүсээс илүү агуу гэж чи хэлж чадах уу? Тэд замыг зассан уу, эсвэл үргэлжлүүлсэн үү гэдэг нь чухал биш; харин тэдний ажлын мөн чанар болон төлөөлж буй ялгамж чанар нь хамгийн чухал юм. Тийм биз дээ? Бурхан хүмүүсийн дунд ажиллахаар зорьсон тул зам засах ажлыг хийж чадах хүмүүсийг өсгөх хэрэгтэй болсон. Иохан дөнгөж номлож эхлэх үедээ “Та нар Эзэний замыг бэлдэж, Түүний замыг шулуун болгогтун.” “Гэмшицгээ: учир нь тэнгэрийн хаанчлал ойрхон байна” гэж хэлсэн юм. Тэр бүр эхнээсээ л ингэж ярьсан, тэгвэл яагаад эдгээр үгийг хэлж чадсан юм бэ? Эдгээр үгийг хэлсэн дарааллын хувьд тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг эхлээд ярьсан хүн нь Иохан байсан ба Есүс дараа нь ярьсан. Хүний үзлээр бол, шинэ замыг нээсэн хүн нь Иохан байсан бөгөөд иймээс мэдээж Иохан Есүсээс илүү агуу байлаа. Гэхдээ Иохан өөрийгөө Христ гэж хэлээгүй, Бурхан түүнийг Бурханы хайртай Хүү гэж гэрчлээгүй, харин замыг нээж, Эзэний замыг бэлтгэхэд л түүнийг ашигласан төдий юм. Тэр Есүсийн замыг зассан боловч Есүсийн өмнөөс ажиллаж чадаагүй. Хүний бүх ажлыг ч бас Ариун Сүнс хадгалж ирсэн юм.

Хуучин Гэрээний эрин үед Ехова замыг залж явсан, Еховагийн ажил Хуучин Гэрээний бүхий л эрин үе болон Израиль дахь бүх ажлыг төлөөлсөн. Мосе ердөө л газар дээрх энэ ажлыг баримталсан бөгөөд түүний хөдөлмөрийг хүний хамтын ажиллагаа гэж тооцдог. Тухайн үед Ехова үг хэлж, Мосег дуудан, Израилийн ард түмэн дундаас Мосег өргөж, Мосегоор тэднийг удирдуулан цөл рүү болон Канаан руу явуулсан. Энэ нь Мосегийн өөрийн ажил байгаагүй, харин Еховагийн биечлэн удирдан чиглүүлсэн ажил байсан тул Мосег Бурхан гэж нэрлэж болохгүй. Мосе ч бас хууль тогтоосон, гэхдээ энэ хуулийг Ехова биечлэн зарлигдсан. Тэрээр ердөө л Мосегоор үүнийг хэлүүлсэн юм. Есүс ч бас тушаал гаргасан, мөн Хуучин Гэрээний хуулийг хүчингүй болгож, шинэ эрин үеийн тушаалыг гаргасан. Есүс яагаад Бурхан Өөрөө мөн бэ? Учир нь энд ялгаа бий. Тухайн үед Мосегийн хийсэн ажил эрин үеийг төлөөлөөгүй, шинэ замыг ч нээгээгүй; түүнийг Ехова удирдан чиглүүлж байсан ба тэр ердөө л Бурханы ашиглаж байсан нэгэн байв. Есүсийг ирэх үед Иохан зам засах ажлын алхмыг гүйцэтгэж, тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг түгээж эхэлсэн (Ариун Сүнс үүнийг эхлүүлсэн юм). Есүс ирэх үедээ Өөрийн ажлыг шууд хийсэн боловч Түүний ажил болон Мосегийн ажил хоорондоо асар их ялгаатай байлаа. Исаиа ч бас олон зөгнөл хэлсэн, гэтэл тэр яагаад Бурхан Өөрөө байгаагүй вэ? Есүс тийм ч олон зөгнөл хэлээгүй, гэтэл Тэр яагаад Бурхан Өөрөө байсан бэ? Тухайн үеийн Есүсийн ажил бүгд Ариун Сүнснээс ирсэн гэж хэн ч хэлж зүрхлээгүй, мөн энэ нь бүгд хүний хүслээс гарсан, эсвэл бүхэлдээ Бурханы Өөрийн ажил байсан гэж ч хэлж зүрхлээгүй. Хүн ийм зүйлсийг судалж шинжлэх ямар ч аргагүй байсан. Исаиагийн хийсэн тэр ажил, хэлсэн тийм зөгнөлүүд бүгд Ариун

Сүнснээс ирсэн гэж хэлж болно; тэдгээр нь шууд Исаиагаас өөрөөс нь гараагүй, харин Еховагаас ирсэн илчлэл байсан юм. Есүс асар их хэмжээний ажил хийгээгүй, олон үг хэлээгүй, олон зөгнөл ч хэлээгүй. Түүний номлож байгаа нь хүнд тийм ч өндөр дээд санагдаагүй, гэсэн ч Тэр Бурхан Өөрөө байсан бөгөөд үүнийг хүн тайлбарлашгүй юм. Иоханд, Исаиад, эсвэл Давидад хэн ч, хэзээ ч итгэж байгаагүй, хэн ч, хэзээ ч тэднийг Бурхан, Давид Бурхан, Иохан Бурхан гэж дуудаж байгаагүй; хэн ч, хэзээ ч ингэж хэлээгүй ба зөвхөн Есүсийг л Христ гэж дуудсан. Бурханы гэрчлэлийн дагуу, Түүний хийсэн ажил, хэрэгжүүлсэн үйлчлэлийн дагуу энэ ангилал хийгдсэн. Абрахам, Давид, Иошуа, Даниел, Исаиа, Иохан, Есүс гэх зэрэг Библийн агуу хүмүүсийн тухайд гэвэл, тэдний хийсэн ажлаар дамжуулан хэн нь Бурхан Өөрөө байсан, ямар төрлийн хүмүүс нь эш үзүүлэгчид, аль нь элч нар байсан бэ гэдгийг чи ялган таньж чадна. Хэнийг нь Бурхан ашиглаж байсан, хэн нь Бурхан Өөрөө байсан гэдэг нь тэдний хийсэн ажлын мөн чанар болон төрлөөр ялгагдаж, тодорхойлогддог. Хэрвээ чи тодорхой ялган таньж чаддаггүй бол Бурханд итгэх гэдэг юу гэсэн үг болохыг мэдэхгүй байгааг чинь энэ нь нотолно. Есүс маш олон үг хэлж, маш их ажил хийж, ялангуяа олон гайхамшиг үзүүлсэн учраас Тэр бол Бурхан юм. Үүний адилаар Иохан ч гэсэн ихээхэн ажил хийж, олон үг хэлсэн, Мосе ч гэсэн адилхан; яагаад тэднийг Бурхан гэж нэрлээгүй вэ? Адамыг Бурхан шууд бүтээсэн; зүгээр л бүтээл гэж дуудагдахын оронд тэр яагаад Бурхан гэж дуудагдаагүй вэ? Хэрвээ хэн нэгэн чамд “Өнөөдөр Бурхан маш их ажил хийж, олон үг хэлсэн; Тэр бол Бурхан Өөрөө. Тэгвэл Мосе ч гэсэн маш олон үг хэлсэн болохоор бас Бурхан Өөрөө байх ёстой!” гэж хэлбэл чи түүнээс эргүүлээд ингэж асуух ёстой: “Тэр үед яагаад Бурхан Иоханыг биш, Есүсийг Бурхан Өөрөө хэмээн гэрчилсэн бэ? Иохан Есүсээс өмнө ирээгүй гэж үү? Иохан, Есүс хоёрын ажлын аль нь илүү агуу байсан бэ? Хүний хувьд Иоханы ажил Есүсийнхээс илүү агуу харагдаж байсан, тэгвэл яагаад Ариун Сүнс Иоханд биш, харин Есүст гэрчлэл хийсэн бэ?” Өнөөдөр ч гэсэн үүнтэй адил зүйл тохиолдож байгаа! Мосе Израилийн ард түмнийг удирдаж байх тэр үед Ехова үүлэн дундаас түүнтэй ярьсан. Мосе шууд яриагүй, харин ч Ехова түүнийг шууд залж чиглүүлж байсан. Энэ нь Хуучин Гэрээний Израилийн ажил байсан юм. Мосегийн дотор Сүнс ч, Бурханы оршихуй ч байгаагүй. Тэрээр уг ажлыг хийж чадаагүй тул түүний хийсэн ажил болон Есүсийн хийсэн ажлын хооронд ихээхэн ялгаа байдаг. Яагаад гэвэл, тэдний хийсэн ажил өөр байсан! Тухайн хүн Бурханаар ашиглагддаг, эсвэл эш үзүүлэгч, элч, эсвэл Бурхан Өөрөө мөн эсэхийг түүний ажлын шинж чанараар ялган таньж болох ба энэ нь эргэлзээг чинь эцэслэнэ. Зөвхөн хурга л долоон лацыг нээж чадна гэж Библид бичигдсэн байдаг. Эрин үеүдийн туршид тэр агуу хүмүүсийн дунд судрыг тайлбарлагчид олон байсан, иймээс чи тэднийг бүгдийг нь Хурга гэж хэлж чадах уу? Тэдний тайлбар бүгд Бурханаас ирдэг гэж чи хэлж чадах уу? Тэд бол ердөө судрыг тайлбарлагчид; тэдэнд Хурганы ялгамж чанар байхгүй. Тэд яаж долоон лацыг нээхэд тохирох юм бэ? “Зөвхөн Хурга л долоон лацыг нээж чадна” гэдэг нь

үнэн боловч Тэр зөвхөн долоон лацыг нээхээр ирдэг юм биш; энэ ажлыг хийх шаардлагагүй, энэ нь тохиолдлоор хийгддэг. Тэр Өөрийн ажлын талаар тов тодорхой мэдэж байдаг; Түүний хувьд судрыг тайлбарлахад их цаг зарцуулах шаардлагатай юу? Зургаан мянган жилийн ажилд “Судрыг тайлбарлах Хурганы эрин үе” гэдгийг нэмэх ёстой гэж үү? Тэр шинэ ажил хийхээр ирсэн боловч бас өнгөрсөн үеийн ажлын талаар зарим илчлэл өгч, зургаан мянган жилийн ажлын тухай үнэнийг хүмүүст ойлгуулдаг. Библийн хэтэрхий олон эшлэлийг тайлбарлах хэрэггүй; өнөөдрийн ажил л гол нь, тэр л чухал. Бурхан гагцхүү долоон лацыг эвдэхийн тулд ирсэн юм биш, харин авралын ажил хийхээр ирсэн гэдгийг чи мэдэх ёстой.

Есүс эцсийн өдрүүдэд бууж ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Тэр яг яаж бууж ирэх вэ? Дөнгөж золин аврагдсан, өөрчлөгдөөгүй, эсвэл Бурханаар төгс болгуулаагүй чам мэтийн нүгэлтэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадах уу? Одоо ч гэсэн хуучин хэвээрээ байгаа чиний хувьд, Есүсээр аврууллсан чинь үнэн. Чи Бурханы авралаас үүдэн нүгэлтэн гэж тооцогдохгүй байгаа боловч нүгэлтэй биш, бохир заваан биш гэдгийг чинь энэ нь нотлохгүй. Хэрвээ өөрчлөгдөөгүй юм бол чи яаж ариун байж чадах юм бэ? Дотроо чи бохир заваанаар дүүрч, хувиа хичээсэн, өөдгүй байдаг мөртөө Есүстэй хамт буухыг хүссээр байдаг—тийм азтай явдал байна гэж үү дээ! Бурханд итгэх итгэлдээ чи нэг алхмыг орхисон: Чи зүгээр л золин аврагдсан, гэхдээ өөрчлөгдөөгүй. Чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхын тулд Бурхан чамайг биечлэн өөрчилж, цэвэрлэх ёстой; чи зөвхөн золин аврууллсан бол ариун байдалд хүрч чадахгүй. Ийм маягаар чи Бурханы сайн ерөөлийг хуваалцах эрхгүй байх болно, учир нь чи хүнийг удирдах Бурханы ажилд нэг алхмыг орхигдуулсан, энэ нь өөрчлөгдөж, төгс болох гол алхам юм. Тиймээс дөнгөж золин аврагдсан нүгэлтэн чи Бурханы өв залгамжлалыг шууд өвлөн авч чадахгүй.

Ажлын энэ шинэ үе шатны эхлэл байхгүй бол сайн мэдээ тунхаглагчид, номлогчид, судрыг тайлбарлагчид, агуу сүнслэг хүмүүс гэгддэг та нар хэр хол явахыг хэн мэдэх билээ! Ажлын энэ шинэ үе шатны эхлэлгүйгээр, та нарын ярьдаг зүйл хоцрогдсон байх болно! Энэ нь нэг бол сэнтийд залрах, эсвэл хаан болох биеийн хэмжээг бэлтгэх; өөрийгөө үгүйсгэх, эсвэл биеэ захирах; тэвчээртэй байх, эсвэл бүх зүйлээс хичээл сурах; даруу байдал юм уу хайр байна. Энэ нь улиг болсон зүйл биш гэж үү? Энэ нь зүгээр л нэг зүйлийг өөр нэрээр дуудаж байгаа хэрэг юм! Нэг бол толгойгоо бүтээж, талх хуваах, эсвэл гараа тавин залбирах, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах. Ямар нэг шинэ ажил байж чадах уу? Хөгжлийн хэтийн ирээдүй байж чадах уу? Хэрвээ чи ийм байдлаар үргэлжлүүлбэл хоосон сургаалыг сохроор дагаж, тогтсон журмыг мөрдөнө. Ажил чинь маш сүрлэг гэж та нар итгэдэг ч энэ нь бүгд эртний “хөгшчүүлийн” уламжилж, заасан зүйл байсан гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Та нарын хэлдэг, хийдэг бүхэн тэр хөгшчүүлийн сүүлчийн үг биш гэж үү? Энэ нь тэр хөгшчүүлийн нас барахынхаа өмнө даалгасан зүйл биш гэж үү? Та нарын үйлдэл өнгөрсөн үеийн тэдгээр элч, эш

үзүүлэгчийнхээс илүү гарсан, тэр ч бүү хэл бүх зүйлээс давсан гэж чи бодож байна уу? Ажлын энэ үе шатны эхлэл нь, хаан болж, сэнтийд залрахыг зорьсон Витнесс Лигийн ажлыг гайхан бишрэхийг чинь эцэс болгосон ба биеэ тоосон зан, сагсуурлыг чинь зогсоосон, ингэснээр та нар ажлын энэ үе шатанд хөндлөнгөөс оролцож чаддаггүй. Ажлын энэ үе шат байгаагүй бол та нар аврагдахын аргагүй болтлоо илүү гүн живэх байсан юм. Та нарын дунд хуучин зүйл хэтэрхий их байгаа! Азаар, өнөөдрийн ажил та нарыг буцаан авчирсан; тэгээгүй бол та нар ямар чиглэлд явах байсныг хэн мэдэх билээ! Бурхан бол үргэлж шинэлэг, хэзээ ч хуучин байдаггүй Бурхан тул чи яагаад шинэ зүйлийг эрж хайдаггүй юм бэ? Яагаад үргэлж хуучин зүйлстэй зууралддаг юм бэ? Тиймээс өнөөдөр Ариун Сүнсний ажлыг мэдэх нь хамгийн чухал ач холбогдолтой юм!

ТӨГС БОЛГУУЛСАН ХҮМҮҮС Л УТГА УЧИРТАЙ АМЬДРАЛААР АМЬДАРЧ ЧАДНА

Үнэндээ одоо хийгдэж байгаа ажил бол хүмүүсээр Сатаныг, хуучин өвөг дээдсийг нь орхиулах ажил юм. Үгээр хийдэг бүх шүүлт нь хүн төрөлхтний ялзармал зан чанарыг ил болгож, хүмүүст амьдралын мөн чанарыг ойлгох боломж олгохыг зорьдог. Энэхүү удаа дараагийн шүүлт нь хүмүүсийн зүрх сэтгэлийг зүсдэг. Шүүлт бүр тэдний хувь заяанд шууд нөлөөлдөг бөгөөд зүрх сэтгэлийг нь шархлуулах учиртай, ингэснээр тэд энэ бүх зүйлийг орхиж, улмаар амьдралыг мэдэж авч, энэхүү бузар ертөнцийг мэдэж, мөн Бурханы мэргэн ухаан, төгс хүчит байдлыг болон Сатаны ялзруулсан энэ хүн төрөлхтнийг танин мэдэж чадна. Ийм төрлийн гэсгээлт, шүүлтийг хүлээн авах тусам хүний зүрх сэтгэл төдий чинээ их шархалж, сүнс нь төдий чинээ их сэрэх боломжтой. Дээд зэргээр ялзарсан, хамгийн ихээр мэхлэгдсэн энэ хүмүүсийн сүнсийг сэрээх нь ийм төрлийн шүүлтийн зорилго юм. Хүн сүнсгүй, өөрөөр хэлбэл, сүнс нь аль хэдийн үхсэн бөгөөд Тэнгэр байдаг гэдгийг тэр мэддэггүй, Бурхан байдаг гэдгийг мэддэггүй, мөн өөрийгөө үхлийн ёроолгүй ангалд тэмцэлдэж байгааг ч мэддэггүй нь тодорхой; тэрээр газар дээрх энэ муу ёрын тамд амьдарч байгаагаа ер нь яаж мэдэж чадах юм бэ? Ялзарсан цогцос нь Сатаны завхралаар дамжин Үхэгсдийн оронд унасан гэдгийг тэр яахан мэдэж чадах юм бэ? Газар дээрх бүх зүйлийг хүн төрөлхтөн аль эрт авах юмгүй болтол нь сүйтгэсэн гэдгийг тэр яахан мэдэж чадах юм бэ? Мөн Бүтээгч өнөөдөр газар дэлхий дээр ирээд Өөрийн аварч чадах завхарсан бүлэг хүмүүсийг хайж байгааг тэрээр яахан мэдэж чадах билээ? Хүн боломжтой бүх шүүлт, цэвэршүүлэлтийг туулсны дараа ч гэсэн мунхаг ухамсар нь бас л арай ядан хөдөлж, үнэндээ л мэдрэлгүй шахуу байдаг. Хүн төрөлхтөн үнэхээр доройтжээ! Хэдийгээр ийм төрлийн шүүлт нь тэнгэрээс унадаг ширүүн мөндөртэй адил ч гэсэн хүнд хамгийн их ач тустай. Хүмүүсийг ийнхүү шүүгээгүй бол ямар ч үр дүн гарахгүй байх байсан

бөгөөд хүмүүсийг гаслангийн ёроолгүй ангалаас аварна гэдэг огт боломжгүй байх байсан юм. Хэрвээ энэ ажил байгаагүй бол Үхэгсдийн орноос гарч ирнэ гэдэг хүмүүсийн хувьд маш хэцүү байх байсан, учир нь тэдний зүрх сэтгэл аль эрт үхэж, сүнс нь аль хэдийн Сатанд гишгэчүүлсэн. Доройтлын хамгийн гүнд живсэн та нарыг аврахын тулд та нарыг хашхиран дуудаж, хүчээр шүүх шаардлагатай, тэгсэн цагт л та нарын мөс шиг цэвдэг зүрх сэтгэл сэрэх болно.

Махан бие, тансаглах хүсэл, шунал, хүсэл тачаал чинь та нарын дотор хэтэрхий гүн суусан байдаг. Эдгээр зүйл зүрх сэтгэлийг чинь цаг ямагт хянаж байдаг болохоор энэхүү феодлын, дорой бодлынхоо дөнгийг хөсөр хаяхад та нар хүчин мөхөстдөг. Та нар одоогийн нөхцөл байдлаа өөрчилье гэж ч эрмэлздэггүй, харанхуйн нөлөөнөөс зугтъя гэж ч эрмэлздэггүй. Та нар зүгээр л эдгээр зүйлд хүлэгдсэн байдаг. Та нар ийм амьдрал хэтэрхий зовлонтой, энэ хүний ертөнц хэтэрхий харанхуй гэдгийг мэддэг ч гэсэн амьдралаа өөрчлөх зориг зүрх хэнд чинь ч байдаггүй. Та нар ийм амьдралын бодит байдлаас зугтаж, сүнсээ чөлөөлж, амар амгалан, аз жаргалтай, диваажин мэт орчинд амьдрахыг л хүсэн тэмүүлдэг. Та нар одоогийнхоо амьдралыг өөрчлөхийн тулд хүндрэл бэрхшээл амсах хүсэлгүй байдаг; мөн энэ шүүлт, гэсгээлт дотроос өөрсдийн орох ёстой амьдралыг хайхыг ч хүсдэггүй. Үүний оронд та нар махан биеэс давсан үзэсгэлэнт дэлхий ертөнцийн тухай бодит байдлаас хол тасарсан мөрөөдлийг мөрөөддөг. Та нарын хүсэн тэмүүлдэг амьдрал бол ямар ч зовлон шаналал туулалгүй, амархан олж авч чадах амьдрал юм. Энэ чинь тэр аяараа бодит байдлаас тасархай! Учир нь та нарын хүсэж найддаг зүйл бол махан биед утга учиртай амьдралыг амьдран харуулж, амьдрах хугацаандаа үнэнийг олж авах биш, өөрөөр хэлбэл, үнэний төлөө амьдарч, шударга ёсны төлөө зогсох явдал биш юм. Энэ нь та нарын гэгээлэг, өнгө жавхаатай гэж тооцдог амьдрал биш. Энэ нь та нарт тансаг хээнцэр, утга учиртай амьдрал юм шиг санагддаггүй. Та нарын нүдэнд бол, ийм амьдралаар амьдрах нь шударга бус мэт санагдана! Хэдийгээр өнөөдөр та нар энэ гэсгээлтийг хүлээн авдаг ч эрэлхийлж байгаа зүйл чинь үнэнийг олж авах биш, одоо цагтаа үнэнийг амьдран харуулах ч биш, харин хожим нь махан биеэс ангид аз жаргалтай амьдралд орж чадахын төлөө байдаг. Та нар үнэнийг эрж хайхгүй байна, үнэний төлөө зогсохгүй байна, бас яавч үнэний төлөө оршихгүй байна. Та нар өнөөдрийн оролтыг эрэлхийлдэггүй, оронд нь ирээдүйн талаар, тэр нэг өдөр ямар байх талаар байнга бодож, хөх тэнгэрийг ширтэн, гашуун нулимс урсгаж, нэг л өдөр тэнгэрт хүргүүлэхээ хүлээж байдаг. Ийм бодол чинь аль хэдийн бодит байдлаас тасарсан гэдгийг та нар ойлгохгүй байна уу? Энэ дэлхий дээр бэрхшээл, зовлон туулсан чамайг авч явахаар цаглашгүй сайхан сэтгэлт, энэрэнгүй Аврагч нэг л өдөр гарцаагүй ирнэ, мөн Тэр хохирч, дарлагдсан чиний гомдлыг тайлж, өшөөг чинь эргэлзээгүй авна гэж чи бодсоор л байдаг. Чи нүгэл хилэнцээр дүүрэн биш гэж үү? Чи энэ дэлхий дээр зовж шаналсан цорын ганц хүн гэж үү? Чи өөрөө л Сатаны эзэмшилд унаж зовсон—Бурхан үнэхээр гомдлыг чинь тайлах хэрэгтэй гэж үү? Бурханы шаардлагыг

биелүүлж чаддаггүй хүмүүс бүгд Бурханы дайсан биш гэж үү? Бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй хүмүүс бол антихристүүд биш гэж үү? Сайн үйл хэрэг чинь юуны төлөө байдаг вэ? Тэдгээр нь Бурханыг шүтэн мөргөдөг зүрх сэтгэлийг чинь орлож чадах уу? Чи зүгээр л зарим нэг сайн үйл хийснээр Бурханы ерөөлийг хүртэж чадахгүй, чамайг хохирч, дарлагдсан гээд л Бурхан гомдлыг чинь тайлж, чиний эсрэг буруу зүйлсийн өшөөг авч өгөхгүй. Бурханд итгэдэг атлаа Бурханыг мэддэггүй, гэхдээ сайн үйл хийдэг хүмүүс—тэд бүгд бас гэсгээгддэггүй гэж үү? Чи ердөө л Бурханд итгэж, өөрийн чинь эсрэг хийсэн буруу үйлийн өшөөг авхуулах, цагаатгуулах төдийхнийг л Бурханаас хүсэж, Бурхан чамд толгойгоо өндөрт өргөх өдрийг өгөөсэй гэж хүсдэг. Гэвч чи үнэнд анхаарал хандуулахаас татгалздаг; үнэнийг амьдран харуулахыг ч хүсдэггүй. Энэ хэцүү бэрх, хоосон амьдралаас зайлсхийж бүр ч чаддаггүй. Оронд нь чи махан бие дэх, нүгэлт амьдралаараа амьдрангаа Бурхан руу гомдлыг минь барагдуулж, оршин тогтнолын минь мананг сарниулаач гэсэн горьдсон харцаар харж байдаг. Гэхдээ энэ боломжтой гэж үү? Хэрвээ чамд үнэн байгаа бол чи Бурханыг дагаж чадна. Хэрвээ чи амьдран харуулдаг бол Бурханы үгийн илрэл байж чадна. Хэрвээ чи амьтай бол Бурханы ерөөлийг эдэлж чадна. Үнэнийг эзэмшдэг хүмүүс л Бурханы ерөөлийг эдэлж чадна. Бурхан өөрсдийгөө л хайрладаг, Сатаны заль мэхэнд урхидуулсан хүмүүсийг бус, харин бүхий л зүрх сэтгэлээсээ Түүнийг хайрлаж, бэрхшээл, зовлон туулдаг хүмүүсийг гарцаагүй цагаатгадаг. Үнэнийг хайрладаггүй хүмүүст сайн сайхан зүйл хаанаас байх билээ? Махан биеэ л хайрладаг хүмүүст яаж зөв шударга байдал байх юм бэ? Зөв шударга, сайн сайхан байдал хоёр нь зөвхөн үнэнтэй хамааралтай яригдах асуудал биш гэж үү? Тэдгээр нь Бурханыг бүхий л зүрх сэтгэлээсээ хайрладаг хүмүүст зориулагдсан байдаггүй гэж үү? Үнэнийг хайрладаггүй, илжирсэн цогцос төдий хүмүүс—энэ бүх хүн ёрын мууг өвөрлөдөг биш гэж үү? Үнэнийг амьдран харуулах чадваргүй хүмүүс—тэд бүгд үнэний дайсан биш гэж үү? Тэгвэл та нар ямар вэ?

Хэрвээ чи эдгээр харанхуйн нөлөөнөөс мултарч, тэдгээр бохир зүйлээс өөрийгөө салгаж, ариун болж чадвал үнэнийг эзэмшдэг гэсэн үг. Уг чанар чинь өөрчлөгдсөн юм биш, харин чи үнэнийг хэрэгжүүлж, махан биеэ хаях чадвартай байгаа л хэрэг юм. Энэ нь цэвэрлэгдсэн хүмүүст байдаг зүйл юм. Байлдан дагуулах ажлын гол зорилго гэвэл хүнд үнэнийг эзэмшүүлэхийн тулд хүн төрөлхтнийг цэвэрлэх явдал, учир нь хүн одоо хэтэрхий бага үнэнийг ойлгодог билээ! Энэ хүмүүст байлдан дагуулах ажлыг хийх нь хамгийн гүн гүнзгий ач холбогдолтой. Та нар бүгд харанхуйн нөлөөнд автаж, гүн гүнзгий хорлогдсон. Тэгвэл энэ ажлын зорилго нь хүний уг чанарыг мэдэх, улмаар үнэнийг амьдран харуулах боломжийг та нарт олгоход оршдог. Төгс болгуулна гэдэг бол бүх бүтээгдсэн зүйлийн хүлээн авах ёстой зүйл юм. Хэрвээ энэ үе шатны ажил нь хүмүүсийг төгс болгох явдлыг л зөвхөн агуулдаг байсан бол үүнийг Англи, Америк юм уу, Израилд хийж болох байсан; ямар ч үндэстний хүмүүс дээр хийж болох байсан. Гэвч байлдан дагуулах

ажил нь шалгууртай. Байлдан дагуулах ажлын эхний алхам нь богино хугацааных байдаг; түүнчлэн үүнийг Сатаныг шившиглэх, бүхий л орчлон ертөнцийг байлдан дагуулахад ашиглах болно. Энэ нь эхний байлдан дагуулах ажил юм. Төгс болгуулна гэдэг нь урт хугацааны өөрчлөлтийн дараа л хүний хүрч чадах зүйл учраас Бурханд итгэдэг ямар ч бүтээл төгс болгуулж чадна гэж хэлж болно. Харин байлдан дагуулагдах бол ондоо. Байлдан дагуулалтын үлгэр загвар, дуурайл нь хамгийн хол хоцорч, хамгийн харанхуйд амьдарч байгаа нэгэн, мөн хамгийн их доройтсон, Бурханыг хүлээн зөвшөөрөх хамгийн дургүй, Бурханд хамгийн дуулгаваргүй хүн байх ёстой. Ийм хүн л яг байлдан дагуулагдах гэдгийг гэрчилж чадна. Байлдан дагуулах ажлын үндсэн зорилго нь Сатаныг ялах явдал, харин хүмүүсийг төгс болгохын үндсэн зорилго бол хүмүүсийг олж авах явдал юм. Байлдан дагуулагдсаныхаа дараа гэрчлэлтэй болох боломжийг хүмүүст олгохын тулд энэхүү байлдан дагуулах ажлыг энд, та нар шиг хүмүүс дээр хэрэгжүүлдэг юм. Зорилго нь гэвэл байлдан дагуулагдсаных нь дараа хүмүүсээр гэрчлэл хийлгэх явдал юм. Байлдан дагуулагдсан энэ хүмүүсийг Сатаныг шившиглэх зорилгод хүрэхэд ашиглах болно. Тэгвэл, байлдан дагуулалтын гол арга барил юу вэ? Гэсгээлт, шүүлт, хараах болон илчлэх гэсэн зөвт зан чанарыг ашиглан хүмүүсийг байлдан дагуулснаар хүмүүс Бурханы зөвт зан чанарыг хараад бүрмөсөн үнэмшдэг. Байлдан дагуулагдах гэдэг нь хүмүүсийг байлдан дагуулж, бүрэн үнэмшүүлэхийн тулд үгийн бодит байдал, эрх мэдлийг ашиглахыг хэлдэг. Төгс болгуулсан хүмүүс байлдан дагуулагдсаныхаа дараа зүгээр ч нэг дуулгавартай болоод зогсохгүй бас шүүлтийн ажлын талаар мэдлэгтэй болж, зан чанараа өөрчилж, Бурханыг мэдэж чадна. Тэд Бурханыг хайрлах замыг туулж, үнэнээр дүүрсэн байдаг. Тэд Бурханы ажлыг хэрхэн туулахыг сурч, Бурханы төлөө зовж бас өөрсдийн гэсэн хүсэлтэй байж чаддаг болдог. Төгс болгуулсан хүмүүс бол Бурханы үгийг туулсныхаа ачаар үнэний талаар бодит ойлголттой болсон хүмүүс юм. Байлдан дагуулагдсан хүмүүс бол үнэнийг мэддэг боловч үнэний бодит утга учрыг хүлээн аваагүй хүмүүс юм. Байлдан дагуулагдсаныхаа дараа тэд дуулгавартай байдаг ч тэдний дуулгавартай байдал нь бүгд шүүлт хүртсэнийх нь л үр дүн байдаг. Тэд олон үнэний бодит утга учрын талаар ямар ч ойлголтгүй явдаг. Тэд аман дээрээ үнэнийг хүлээн зөвшөөрдөг боловч үнэнд ороогүй байдаг; үнэнийг ойлгодог боловч үнэнд туршлагажаагүй байдаг. Төгс болгуулж байгаа хүмүүст гэсгээлт, шүүлт болон амийн хангалт зэрэг ажил хийгдэж байдаг. Үнэнд ороход үнэ цэн өгдөг хүн бол төгс болгуулах хүн юм. Төгс болгуулах хүн, байлдан дагуулагдах хүн хоёрын ялгаа нь үнэнд орох эсэхэд нь оршдог. Үнэнийг ойлгодог, үнэнд орсон, үнэнийг амьдран харуулж байгаа хүмүүс нь төгс болгуулсан хүмүүс юм; үнэнийг ойлгодоггүй, үнэнд ордоггүй, өөрөөр хэлбэл, үнэнийг амьдран харуулдаггүй хүмүүс бол төгс болгуулж чадахгүй хүмүүс билээ. Ийм хүмүүс одоо бүрэн дуулгавартай байж чадвал байлдан дагуулагдана. Хэрвээ байлдан дагуулагдсан хүмүүс үнэнийг эрж хайдаггүй бол—үнэнийг дагадаг боловч үнэнийг амьдран харуулдаггүй бол,

үнэнийг олж харж, сонсдог боловч үнэнийг амьдран харуулахад үнэ цэн өгддөггүй бол—тэд төгс болгуулж чадахгүй. Төгс болгуулах хүмүүс нь төгс болгуулах замд Бурханы шаардлагын дагуу үнэнийг хэрэгжүүлдэг. Үүгээр дамжуулан тэд Бурханы хүслийг биелүүлдэг бөгөөд төгс болдог. Байлдан дагуулах ажил дуусахаас өмнө эцсийг нь хүртэл дагах хэн боловч байлдан дагуулагдсан нэгэн юм, гэвч түүнийг төгс болгуулсан нэгэн гэж хэлж болохгүй. Төгс болгуулсан хүмүүс гэдэг нь байлдан дагуулах ажил дууссаны дараа үнэнийг эрэлхийлж, Бурханаар авхуулж чадах хүмүүсийг хэлдэг. Энэ нь байлдан дагуулах ажил дууссаны дараа гай гамшиг дунд бат зогсож, үнэнийг амьдран харуулдаг хүмүүсийг хэлдэг. Төгс болгуулах, байлдан дагуулагдах хоёрыг ялгадаг зүйл нь ажлын алхмын ялгаа болон хүмүүсийн үнэнийг ойлгож, үнэнд орох түвшний ялгаа юм. Төгс болгуулах замд ороогүй бүх хүн, өөрөөр хэлбэл, үнэнийг олж аваагүй хүмүүс эцэстээ мөн л таягдан хаягдана. Үнэнийг олж авсан, үнэнийг амьдран харуулдаг хүмүүс л Бурханаар бүрэн авхуулж чадна. Өөрөөр хэлбэл, Петрийн дүр төрхийг амьдран харуулдаг хүмүүс нь төгс болгуулсан хүмүүс байхад бусад нь бүгд байлдан дагуулагдсан хүмүүс юм. Байлдан дагуулагдаж байгаа бүх хүнд хийгдэж байгаа ажил нь хараах, гэсгээх, уур хилэнг харуулахаас бүрддэг бөгөөд тэд хараал болон зөв шударга байдлыг хүлээн авдаг билээ. Ийм хүн дээр ажиллана гэдэг нь ёсорхож, боловсон загналгүй илчилнэ гэсэн үг—тэдний доторх ялзарсан зан чанарыг илчилснээр тэд өөрсдөө ухаарч, бүрэн үнэмшдэг. Хүнийг бүрэн дуулгавартай болмогц байлдан дагуулах ажил дуусдаг. Ихэнх хүн одоо хэр нь үнэнийг ойлгох гэж эрж хайхгүй байгаа ч гэсэн, байлдан дагуулалтын ажил дууссан байх болно.

Төгс болгуулна гэвэл хангах ёстой шалгуур гэж бий. Чи шийдэмгий байдал, няцашгүй зан, мөс чанар болон эрэл хайгуулаараа дамжуулан амийн талаар зарим туршлагатай болж, Бурханы хүслийг биелүүлж чадах болно. Энэ бол чиний оролт, эдгээр нь бол төгс болгуулах замд шаардагддаг зүйлс юм. Төгс болгох ажлыг бүх хүн дээр хийж болно. Бурханыг эрэлхийлдэг хэн боловч төгс болгуулж болох ба төгс болгуулах боломж, бололцоотой. Үүнд ямар ч хатуу тогтсон дүрэм байдаггүй. Хүний төгс болгуулж чадах эсэх нь юуг эрэлхийлдэг вэ гэдгээс нь үндсэндээ шалтгаалдаг. Үнэнийг хайрладаг, үнэнийг амьдран харуулах чадвартай хүмүүс төгс болгуулж чадах нь гарцаагүй юм. Үнэнийг хайрладаггүй хүмүүсийг Бурхан сайшаадаггүй; тэдэнд Бурханы шаарддаг амь байдаггүй бөгөөд төгс болгуулж чадахгүй. Төгс болгох ажил нь зөвхөн хүмүүсийг олж авахын төлөө байдаг болохоос Сатантай тулалдах ажлын нэг хэсэг биш юм; байлдан дагуулах ажил нь зөвхөн Сатантай тулалдахын төлөө байдаг бөгөөд Сатаныг ялахын тулд хүмүүсийн байлдан дагуулалтыг ашиглана гэсэн үг юм. Байлдан дагуулалтын ажил бол үндсэн ажил, бүх эрин үед хэзээ ч хийгдэж байгаагүй хамгийн шинэ ажил билээ. Ажлын энэ үе шатны зорилго нь үндсэндээ Сатаныг ялахын тулд бүх хүнийг байлдан дагуулахын төлөө байдаг гэж хэлж болно. Хүмүүсийг төгс болгох ажил—энэ бол шинэ ажил биш. Бурхан махбодод ажиллаж байх үеийн бүх ажил нь хүмүүсийг

байлдан дагуулах үндсэн зорилготой. Энэ нь Нигүүлслийн эрин үеийнхтэй ижил. Цовдлолоор дамжуулан бүх хүн төрөлхтнийг золин аврах нь үндсэн ажил байсан. “Хүмүүсийг олж авах” нь махбод дахь ажлын нэмэлт байсан бөгөөд цовдлолын дараа л хийгдсэн юм. Есүс ирж, Өөрийн ажлыг хийх үедээ гол төлөв үхэл болон Үхэгсдийн орны хүлээсийг ялан дийлэх, Сатаны нөлөөг дийлэх, өөрөөр хэлбэл, Сатаныг ялахад Өөрийн цовдлолыг ашиглах зорилготой байсан юм. Есүсийг цовдлогдсоны дараа л Петр төгс болох замаар алхам алхмаар урагшилж эхэлсэн. Мэдээж тэр Есүсийг ажиллаж байх үед Есүсийг дагадаг хүмүүсийн дунд байсан боловч тухайн хугацаанд төгс болоогүй юм. Харин Есүсийг ажлаа дуусгасны дараа Петр аажмаар үнэнийг ойлгож, дараа нь төгс болсон. Бие махбодтой болсон Бурхан ажлын чухал, шийдвэрлэх үе шатыг богино хугацаанд гүйцэлдүүлэхийн тулд л газар дээр ирдэг болохоос газар дээрх хүмүүсийг төгс болгох зорилготойгоор тэдний дунд урт удаан амьдрахаар ирдэггүй. Тэр ийм ажил хийдэггүй. Тэрээр ажлаа дуусгахын тулд хүн бүрмөсөн төгс болох үеийг хүлээдэггүй. Энэ бол Түүний бие махбод болсны зорилго, ач холбогдол биш юм. Тэрээр хүн төрөлхтнийг төгс болгох маш урт хугацааны ажлыг бус, хүн төрөлхтнийг аврах богино хугацааны ажлыг хийх гэж л ирдэг. Хүн төрөлхтнийг аврах ажил нь бэлгэдлийн чанартай, шинэ эрин үеийг эхлүүлэх чадвартай. Үүнийг богино хугацаанд дуусгаж болдог. Харин хүн төрөлхтнийг төгс болгохын тулд хүнийг тодорхой түвшинд хүргэх шаардлагатай болдог ба үүнд урт хугацаа зарцуулагддаг. Энэ ажлыг Бурханы Сүнс хийх ёстой, гэхдээ энэ нь Түүний махбод дахь ажлынхаа үеэр ярьсан үнэний суурин дээр хийгддэг. Тэр хүн төрөлхтнийг төгс болгох зорилгодоо хүрэхийн тулд, урт хугацааны хариулах ажлыг хийлгүүлэхээр элч нарыг өргөх ажлаар дамжин хийгддэг. Бие махбодтой болсон Бурхан энэ ажлыг хийдэггүй. Тэр хүмүүсийг ойлгог гэж амийн замын тухай л ярьж, үнэнийг хэрэгжүүлэх явцад нь хүмүүсийн дэргэд байнга хамт байхын оронд хүн төрөлхтөнд зөвхөн үнэнийг өгдөг, учир нь Түүний үйлчлэлд энэ хамааралгүй юм. Иймээс хүн үнэнийг бүрэн ойлгож, бүрэн олж авах өдрийг хүртэл Тэрээр хүнийг дагалдахгүй. Хүн Бурханд итгэх зөв замд албан ёсоор орж, төгс болгуулах зөв замд хөл тавих үед махбод дахь Түүний ажил дуусдаг. Мэдээж энэ нь бас Түүний, Сатаныг бүрмөсөн ялж, дэлхий ертөнцийг ялан дийлсэн байх үе юм. Тэрээр, хүн тухайн үед үнэнд үнэхээр орсон эсэхийг ч, хүний амь үлэмж том байна уу, жижиг байна уу гэдгийг ч тоодоггүй. Эдгээрийн аль нь ч махбод дахь Түүний зохицуулах ёстой зүйл биш; эдгээрийн аль нь ч бие махбодтой болсон Бурханы үйлчлэл дотор байдаггүй. Тэр зорьсон ажлаа дуусгамагцаа махбод дахь ажлаа дуусгадаг. Иймээс бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил нь зөвхөн Бурханы Сүнсний шууд хийж чаддаггүй ажил юм. Түүнчлэн энэ нь газар дээрх урт хугацааны ажил биш, харин богино хугацааны авралын ажил юм.

Та нарын хэв чанарыг өсгөх нь Миний ажлын цар хүрээнд багтдаггүй. Хэв чанар чинь хэтэрхий дорд байгаа учраас л үүнийг хийгээч гэж Би та нараас хүсдэг. Үнэндээ энэ нь төгс болгох ажлын нэг хэсэг биш; харин та нар дээр хийгдэж байгаа

нэмэлт ажил юм. Өнөөдөр та нар дээр гүйцэтгэж байгаа ажлыг хэрэгцээний чинь дагуу хийдэг. Энэ нь хүн бүрийн онцлогийг харгалздаг бөгөөд төгс болгуулж буй хүн болгоны орох ёстой зам биш юм. Та нарын хэв чанар өмнө нь төгс болгуулсан хэн бүхнийхээс дорд учраас энэхүү ажил та нар дээр хийх үед хэтэрхий олон саад гардаг. Төгс болгуулах байнууд өөр өөр учраас Би та нарын дунд энэхүү нэмэлт ажлыг хийж байна. Үндсэндээ Бурхан газар дээр ирэх үедээ Өөрийн зүй ёсны хариуцлагынхаа хүрээнд л ажлаа гүйцэтгэдэг ба хамааралгүй өөр хэрэг явдалд сатаардаггүй. Тэрээр гэр бүлийн асуудал, хүмүүсийн амьдралд оролцдоггүй. Тэр иймэрхүү жижиг сажиг зүйлсэд огтхон ч санаа тавьдаггүй; эдгээр нь Түүний үйлчлэлийн нэг хэсэг биш юм. Гэвч та нарын хэв чанар Миний шаардсанаас долоон дор—үнэндээ огт харьцуулах аргагүй бөгөөд энэ нь ажилд туйлын их саад тээг болдог. Үүнээс гадна, энэ ажлыг Хятадын энэ газар нутаг дахь хүмүүсийн дунд хийх ёстой. Та нар үнэхээр боловсрол муутай болохоор Надад шулуухан ярьж, та нараас өөрсдийгөө боловсруулахыг шаардахаас өөр сонголт байдаггүй. Энэ нь нэмэлт ажил гэдгийг Би та нарт хэлсэн, гэхдээ энэ нь бас та нарт байх ёстой зүйл, төгс болгуулахад чинь ач тустай зүйл юм. Үнэндээ боловсрол, биеэ хэрхэн авч явах тухай, амьдралын тухай үндсэн мэдлэг бол та нарт угаасаа л байх ёстой зүйлс юм; Би эдгээр зүйлийн талаар та нарт ярьж байх ёсгүй. Гэвч та нарт эдгээр зүйл байхгүй болохоор хорвоод аль хэдийн мэндэлсний чинь дараа Би та нарт эдгээр зүйлийг сургах ажлыг хийхээс өөр аргагүй болдог. Та нар Миний тухай олон үзэл өвөрлөдөг ч гэсэн, Би бас л та нараас үүнийг, хэв чанараа өсгөхийг шаардсаар л байдаг. Ирээд энэ ажлыг хийнэ гэдэг бол Миний санаа зорилго биш, учир нь Миний ажил бол ердөө л та нарыг байлдан дагуулах, та нарыг шүүснээрээ бүрэн итгэл үнэмшлийг чинь олж авах, улмаар та нарын орох ёстой амийн замыг зааж үзүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, Би та нарыг үгээрээ байлдан дагуулах хэрэг байгаагүй бол та нарын хэр боловсролтой, амьдралын талаар мэдлэгтэй эсэх нь Надад огт хамаагүй байх байсан юм. Энэ бүхнийг, байлдан дагуулах ажлаас гарах үр дүнг баттай болгохын тулд, мөн дараагаар нь та нарыг төгс болгохын төлөө нэмэлтээр хийж байна. Энэ нь байлдан дагуулах ажлын хэсэг биш юм. Та нар дорд хэв чанартай, залхуу, хайнга, мунхаг, ухвар мөчид, үхээнц бөгөөд усан тэнэг учраас—та нар хэтэрхий хэвийн бус учраас—Би та нараас эхлээд хэв чанараа өсгө гэж шаарддаг. Төгс болохыг хүссэн хэн боловч тодорхой шалгуурт тэнцэх ёстой. Төгс болохын тулд хүн эрүүл, саруул ухаантай байж, утга учиртай амьдралаар амьдрахад бэлэн байх ёстой. Хэрвээ чи дэмий амьдралаар амьдрахыг хүсдэггүй, үнэнийг эрэлхийлдэг, хийдэг бүхэндээ чин сэтгэлээсээ ханддаг маш хэвийн хүн чанартай нэгэн бол төгс болох шалгуурыг хангаж байна.

Та нарын дунд хийж байгаа ажлыг хийх хэрэгтэй ажлуудын дагуу та нар дээр хэрэгжүүлж байгаа юм. Энэ хүмүүс байлдан дагуулагдсаны дараа бүлэг хүмүүс төгс болгуулах болно. Тиймээс одоогийн ажлын ихэнх нь бас та нарыг төгс болгох зорилгод бэлдэж байгаа, яагаад гэвэл, үнэнээр өлсөж байгаа, төгс болгуулж чадах

хүмүүс олон байдаг. Байлдан дагуулалтын ажлыг та нар дээр явуулаад, цааш өөр ажил хийгээгүй бол үнэнийг хүсэн тэмүүлдэг зарим хүн үүнийг олж авч чадахгүй байх байсан бус уу? Одоогийн ажил нь хожим хүмүүсийг төгс болгох замыг нээхээр зорьдог. Хэдийгээр Миний ажил ердөө л байлдан дагуулалт боловч Миний ярьдаг амийн зам нь ямартай ч хожим хүмүүсийг төгс болгох бэлтгэл юм. Байлдан дагуулалтын дараах ажил нь хүмүүсийг төгс болгоход чиглэдэг, иймээс төгс болгуулах суурийг тавихын тулд байлдан дагуулалтыг хийдэг. Хүн байлдан дагуулагдсаныхаа дараа л төгс болж чадна. Яг одоо үндсэн ажил бол байлдан дагуулах явдал; хожим нь үнэнийг эрж хайж, үнэнийг хүсэн хүлээдэг хүмүүсийг төгс болгох болно. Төгс болгуулах нь хүмүүсийн оролтын эерэг талуудтай хамааралтай байдаг: Чи Бурханыг хайрладаг зүрх сэтгэлтэй юу? Энэ замаар алхахдаа чи хэр гүн туршлага авсан бэ? Бурханыг хайрлах хайр чинь хэр ариун бэ? Үнэнийг хэрэгжүүлэхдээ чи хэр нарийн чанд вэ? Төгс болгуулахын тулд хүн, хүн чанарын бүх талын тухай үндсэн мэдлэгтэй байх ёстой. Энэ нь үндсэн шаардлага юм. Байлдан дагуулагдсаныхаа дараа төгс болгуулж чадахгүй бүх хүн, зан чанар нь өөрчлөгдөөгүй, Сатанд харьяалагддаг хэвээр байдаг тул хүчин зүтгэгч болж, эцэстээ гал болон хүхэрт нуурт ч хаягдан, ёроолгүй нүхэнд ч мөн унах болно. Хэрвээ хүнд төгс болгуулах нөхцөл шаардлагыг хангахгүй бол тэр хүн хэрэгцээгүй—хог шаар, хэрэгсэл, галын шалгалтыг тэсвэрлэж чадахааргүй зүйл билээ! Яг одоогийн Бурханыг гэх хайр чинь хэр агуу вэ? Өөрийгөө үзэн ядах сэтгэл чинь хэр их вэ? Чи Сатаны тухай үнэндээ хэр их мэдэх вэ? Та нар шийдвэртээ сэтгэл шулуудсан уу? Та нарын хүний амьдрал сайн зохион байгуулалттай юу? Та нарын амьдрал өөрчлөгдсөн үү? Та нар шинэ амьдралаар амьдарч байна уу? Амьдралыг үзэх үзэл чинь өөрчлөгдсөн үү? Хэрвээ эдгээр зүйл өөрчлөгдөөгүй бол чи ухарч няцахгүй байлаа ч гэсэн, төгс болгуулж чадахгүй; чи ердөө л байлдан дагуулагджээ. Чамайг турших цаг болоход чамд үнэн дутагдаж байдаг, хүн чанар чинь хэвийн бус бөгөөд чи яг л ачлагын мал шиг дорд байдаг. Чи байлдан дагуулагдах гэсэн үр дүнд л хүрэх болно, чи ердөө л Миний байлдан дагуулсан эд зүйл болох болно. Илжиг эзнийхээ ташуурын амтыг үзмэгцээ айдастай болж, эзнээ харах болгондоо адайрлахаас эмээдэг шиг, чи ч гэсэн ийм номхорсон илжиг юм. Хэрвээ хүнд эдгээр эерэг тал хомс, харин идэвхгүй, айдастай, бүх зүйлд хулчийж, ухарч няцдаг, аливааг тодорхой ялган таньж чаддаггүй, үнэнийг хүлээн авч чаддаггүй, одоо ч гэсэн хэрэгжүүлэлтийн замгүй, Бурханыг хайрлах зүрх сэтгэл бүр ч байхгүй бол—хэрвээ хүн, хэрхэн Бурханыг хайрлах, хэрхэн утга учиртай амьдралаар амьдрах, хэрхэн жинхэнэ хүн байх талаар ямар ч ойлголтгүй бол—ийм хүн яаж Бурханд гэрчлэл хийж чадах юм бэ? Амьдрал чинь өчүүхэн үнэ цэнтэй, чи бол номхорсон илжигнээс цаашгүй амьтан гэдгийг энэ харуулах болно. Чи байлдан дагуулагдсан боловч энэ чинь ердөө л чи агуу улаан лууг хаясан, эзэмшилд нь захирагдахаас татгалздаг гэсэн үг; энэ нь чи Бурхан байдагт итгэдэг, Бурханы бүх төлөвлөгөөг дуулгавартай дагахыг хүсдэг ба огтхон ч гомдоллодоггүй гэсэн үг юм. Гэхдээ эерэг

талууд дээр чи Бурханы үгийг амьдран харуулж, Бурханыг илэрхийлэх чадвартай юу? Эдгээрийн аль нь ч үгүй бол чи Бурханаар авхуулаагүй, зүгээр л номхорсон илжиг гэсэн үг юм. Чамд сэтгэл татам зүйл юу ч байхгүй бөгөөд Ариун Сүнс чиний дотор ажилладаггүй. Хүн чанар чинь хэтэрхий дутуу дулимаг бөгөөд Бурхан чамайг ашиглах боломжгүй. Чи Бурханаар хүлээн зөвшөөрөгдөж, үл итгэгч араатнууд болон амьд үхдэлүүдээс зуу дахин илүү байх ёстой—энэ түвшинд хүрсэн хүмүүс л төгс болгуулахад тохирдог. Хүн чанартай, мөс чанартай байвал л хүн Бурханаар ашиглуулахад тохирно. Төгс болгуулсан үед чинь л та нарыг хүн гэж тооцож болно. Төгс болгуулсан хүмүүс л утга учиртай амьдралаар амьдардаг хүмүүс юм. Ийм хүмүүс л Бурханы төлөө цангинасан гэрчлэл хийж чаддаг.

ТА НАР БАЙР СУУРИЙН ЕРӨӨЛИЙГ ХОЙШ ТАВЬЖ, ХҮНИЙГ АВРАХ БУРХАНЫ ХҮСЛИЙГ ОЙЛГОХ ЁСТОЙ

Хүний үзэл бодлоор бол, Моабын үр удам бүрэн төгс болгуулах боломжгүй, тийм болгуулах ч эрхгүй. Нөгөө талаар, Давидын хүүхдүүдэд гарцаагүй найдвар байгаа бөгөөд үнэндээ бүрэн төгс болгуулж чадна. Хэрвээ хүн Моабын үр удам мөн бол бүрэн төгс болгуулж чадахгүй. Одоо ч гэсэн та нарын дунд хийгдэж байгаа ажлын ач холбогдлыг та нар мэдэхгүй хэвээр байдаг; энэ үе шатанд та нар зүрх сэтгэлдээ өөрсдийн хэтийн ирээдүйг агуулдаг бөгөөд тэдгээрийг орхихыг хүсдэггүй. Өнөөдөр Бурхан яагаад та нар мэтийн хамгийн зохисгүй хүмүүсийн бүлэгт ажиллахаар сонгосныг хэн ч тоодоггүй. Тэрээр энэ ажилд алдаа гаргасан байж болно гэж үү? Энэхүү ажил нь түр зуурын хайнга явдал уу? Моабын хүүхдүүд гэдгийг чинь үргэлж мэддэг байсан Бурхан яагаад яг та нарын дунд ажиллахаар бууж ирсэн юм бэ? Та нар хэзээ ч ингэж бодож байгаагүй юу? Бурхан Өөрийн ажлыг хийхдээ үүнийг хэзээ ч бодолцож үздэггүй юү? Тэр яаруу байдлаар авирладаг уу? Моабын үр удам гэдгийг чинь Тэр бүр эхнээсээ мэддэг байгаагүй гэж үү? Та нар эдгээр зүйлийг бодолцож үзэхээ мэддэггүй юм уу? Та нарын үзэл хааччихаа вэ? Эрүүл саруул сэтгэлгээ чинь самуурчихсан юм уу? Ухаалаг байдал болон мэргэн ухаан чинь хааччихаа вэ? Та нар тийм уужим сэтгэлтэй болохоор ийм жаахан хэрэг явдлыг анхаардаггүй юм уу? Оюун санаа чинь өөрийн хэтийн ирээдүй, хувь заяа гэх мэт зүйлсэд хамгийн мэдрэмтгий байдаг боловч өөр юуны ч тухайд бол хөшүүн, мангуу, үнэхээр мэдлэггүй байдаг. Та нар ер нь яг юунд итгэдэг юм бэ? Өөрсдийн хэтийн ирээдүйд үү? Эсвэл Бурханд уу? Чи үзэсгэлэнтэй сайхан хүрэх газартаа л итгэдэггүй гэж үү? Хэтийн ирээдүйдээ л итгэдэггүй гэж үү? Амийн замын хэр ихийг чи одоо ойлгодог вэ? Чи хэр ихийг олж авсан бэ? Одоо Моабын үр удам дээр хийгдэж байгаа ажил та нарыг доромжлохын тулд хийгддэг гэж чи бодож байна уу? Энэ нь үзэшгүй муухай байдлыг чинь ил болгохын тулд зориуд хийгддэг үү? Та

нараар гэсгээлтийг хүлээн зөвшөөрүүлээд, дараа нь та нарыг галт нуур луу шидэхийн тулд зориуд хийгддэг үү? Та нарт ямар ч хэтийн ирээдүй байхгүй гэж Би хэзээ ч хэлээгүй, та нар устгагдаж, мөхөх ёстой гэж бүр ч хэлээгүй. Би олны өмнө тийм зүйл зарласан гэж үү? Ямар ч найдвар байхгүй гэж чи хэлдэг, гэхдээ энэ нь чиний гаргасан дүгнэлт биш гэж үү? Энэ нь чиний өөрийн сэтгэхүйн үр нөлөө биш гэж үү? Чиний өөрийн дүгнэлт тооцогдох уу? Хэрвээ Би чамайг ерөөгдөөгүй гэж хэлбэл чи гарцаагүй сүйрлийн бай байх болно; хэрвээ Би чамайг ерөөгдсөн гэж хэлбэл чи гарцаагүй устгагдахгүй. Би чамайг Моабын удам гэж л хэлж байна; чамайг устгагдана гэж Би хэлээгүй. Зүгээр л Моабын үр удам хараагдсан бөгөөд нэг төрлийн завхарсан хүмүүс юм. Нүглийг урьд нь дурдсан; та нар бүгд нүгэлтэй биш гэж үү? Нүгэлтнүүд бүгд Сатанаар завхруулагдаагүй гэж үү? Нүгэлтнүүд бүгд Бурханыг эсэргүүцэж, Түүний эсрэг тэрсэлдэггүй гэж үү? Бурханыг эсэргүүцдэг хүмүүс хараагдах бус уу? Нүгэлтнүүд бүгд устгагдах ёстой бус уу? Тэр тохиолдолд мах цустай хүмүүсийн дундаас хэн аврагдаж чадах юм бэ? Та нар яаж өнөөдрийг хүртэл амьд үлдэж чадсан байх юм бэ? Та нар Моабын үр удам учраас сөрөг болсон; та нар бас нүгэлт хүмүүс гэж тооцогддог бус уу? Та нар яаж өдий хүрсэн юм бэ? Төгс болгох талаар дурдах үед та нар жаргалтай болдог. Асар их гай зовлон туулах ёстой гэдгээ сонссоны дараа энэ нь та нарыг бүр ч их ерөөлтэй болгоно гэж та нарт санагддаг. Гай зовлонгоос гарч ирсний дараа ялагч болж чадна, түүнчлэн энэ нь чамайг гэх Бурханы агуу ерөөл, агуу өргөмжлөл гэж чи боддог. Моабыг дурдангуут та нарын дунд үймээн үүсдэг; насанд хүрэгчид, хүүхдүүд ялгаагүй үгээр хэлэхийн аргагүй уйтгар гунигийг мэдэрч, зүрх сэтгэлд чинь ямар ч баяр хөөр байдаггүй ба та нар бүгд төрсөндөө харамсдаг. Ажлын энэ үе шат Моабын үр удам дээр хийгдэж буйн ач холбогдлыг та нар ойлгодоггүй; та нар өндөр байр суурь эрж хайхаа л мэддэг бөгөөд ямар ч найдвар байхгүй гэж бодогдох болгонд ухарч няцдаг. Төгс болгох болон ирээдүйд хүрэх газрыг дурдангуут та нар баярладаг; та нар ерөөл хүртэж, сайн хүрэх газартай болохын тулд Бурханд итгэлээ өгсөн. Зарим хүн одоо өөрсдийн байр сууриас болж айн сандардаг. Тэд дорд үнэ цэн, доогуур байр суурьтай учраас төгс болгуулахаар эрэлхийлэхийг хүсдэггүй. Эхлээд төгс болгох тухай ярьсан, дараа нь Моабын үр удмын тухай дурдсан тул хүмүүс урьд нь дурдагдсан төгс болгох замыг няцаасан. Учир нь та нар эхнээс нь дуустал энэ ажлын ач холбогдлыг хэзээ ч мэдээгүй, мөн үүний ач холбогдлыг ч тоодоггүй. Та нарын биеийн хэмжээ хэтэрхий жаахан бөгөөд өчүүхэн төдий үймээнийг ч тэвчиж чаддаггүй. Байр суурь чинь хэтэрхий дорд гэдгийг харах үедээ та нар сөрөг болж, үргэлжлүүлэн эрж хайх итгэлээ алддаг. Хүмүүс ердөө нигүүлсэлд хүрсэн түвшин болон амар амгалангийн таашаалыг л итгэлийн бэлгэ тэмдэг гэж авч үзээд, ерөөл эрж хайхыг Бурханд итгэх итгэлийнх нь үндэс гэж үздэг. Тун цөөхөн хүн Бурханыг мэдэхээр эрж хайдаг, эсвэл өөрсдийн зан чанар дахь өөрчлөлтийг эрж хайдаг. Өөрсдийнхөө итгэлд хүмүүс, тохиромжтой хүрэх газар, хэрэгтэй бүх нигүүлслийг Бурханаар өөрсдөдөө өгүүлж, Бурханыг өөрсдийн зарц болгож, хэзээ ч, хэдийд ч

хоорондоо зөрчилтэй байхгүйн тулд амар тайван, нөхөрсөг харилцаагаа хадгалахад Бурханыг хүргэхээр чармайдаг. Өөрөөр хэлбэл, тэдний Бурханд итгэх итгэл нь, өөрсдийнх нь бүх шаардлагад нийцэж, Библиэс уншсан “Би та нарын бүх залбирлыг сонсоно” хэмээх үгийн дагуу залбирсан бүхнийг нь тэдэнд өгөх амлалтыг Бурханаас шаарддаг. Бурхан үргэлж хаана ч, хэдийд ч хүмүүстэй сайхан харилцаатай байдаг өршөөнгүй Аврагч Есүс байсан учраас хэнийг ч шүүхгүй, хэнтэй ч харьцахгүй байхыг тэд Бурханаас хүлээдэг. Хүмүүс Бурханд ингэж итгэдэг: Тэд ердөө ичгүүр сонжуургүйгээр Бурханд шаардлага тавин, өөрсдөө тэрслүү, эсвэл дуулгавартай байх нь хамаагүй Бурхан зүгээр л бүх зүйлийг тэдэнд сохроор хайрлана. Тэд Бурханаас тасралтгүй “өр цуглуулдаг” бөгөөд Бурхан ямар ч эсэргүүцэлгүйгээр тэдэнд “өрөө төлж”, түүнчлэн, хоёр дахин ихийг төлөх ёстой; өөрсдөөс нь ямар нэгэн юм авсан ч бай, үгүй ч бай Бурхан өөрсдийнх нь л эрхшээлд байж болох ба Тэрээр хүмүүсийг дур зоргоороо зохион байгуулж болохгүй, тэр ч бүү хэл, олон жилийн турш нуусан Өөрийн мэргэн ухаан, зөвт зан чанарыг хүссэн үедээ, өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр хүмүүст илчилж болохгүй. Тэд зүгээр л өөрсдийн нүглийг Бурханд улайж, Бурхан зүгээр л тэдгээрийг уучилна, Бурхан үүнээс залхаж болохгүй бөгөөд энэ нь үүрд үргэлжилнэ. Бурхан хүнээр үйлчлүүлэхийн төлөө биш, харин хүнд үйлчлэхийн төлөө ирсэн, мөн хүний зарц байхаар ирсэн гэж Библид тэмдэглэгдсэн байдаг тул тэд зүгээр л Бурханд тушаан, Бурхан өөрсдийг нь дуулгавартай дагана. Та нар үргэлж ингэж итгэсэн бус уу? Та нар Бурханаас ямар нэг зүйл олж авч чадахгүй үедээ зугтахыг хүсдэг; ямар нэгэн зүйлийг ойлгохгүй байх үедээ ихэд дургүйцэж, бүр Түүн рүү төрөл бүрийн хараал зүхэл чулуудахдаа тулдаг. Өөрийн мэргэн ухаан, гайхамшгийг бүрэн илэрхийлэх боломжийг та нар Бурханд Өөрт нь ер олгодоггүй; харин оронд нь зүгээр л түр зуурын амар амгалан, тав тух эдлэхийг хүсдэг. Одоог хүртэл Бурханд итгэх итгэлийн чинь хандлага ердөө нэгэн хэвийн хуучин үзэл бодлоос бүрдсэн. Хэрвээ Бурхан та нарт ялимгүй сүр жавхлан үзүүлэх л юм бол та нар аз жаргалтай бус болдог. Биеийн хэмжээ чинь яг хэр том болохыг та нар одоо харж байна уу? Үнэн хэрэгтээ хуучин үзэл бодол чинь өөрчлөгдөөгүй байхад өөрсдийгөө Бурханд үнэнч гэж бүү бод. Чамд юу ч тохиолдохгүй байх үед бүх зүйл төвөггүй явагдаж байна гэж чи бодоод, Бурханыг дээд зэргээр хайрладаг. Гэхдээ багахан зүйл тохиолдох үед чи Үхэгсдийн орон руу унадаг. Бурханд үнэнч байгаа нь энэ үү?

Хэрвээ байлдан дагуулалтын ажлын сүүлчийн үе шат Израильд эхлэх байсан бол тийм байлдан дагуулалтын ажил ямар ч утга учиргүй байх байв. Уг ажлыг Хятадад, хүмүүс та нар дээр хийх үед л хамгийн их ач холбогдолтой юм. Та нар бол хамгийн ядуу дорой хүмүүс буюу хамгийн дорд байр суурьтай хүмүүс; та нар энэ нийгмийн хамгийн дорд түвшний хүмүүс бөгөөд анх Бурханыг хамгийн бага хүлээн зөвшөөрсөн хүмүүс юм. Та нар Бурханаас хамгийн их холдсон, хамгийн их хохирсон хүмүүс билээ. Энэ үе шатны ажил зөвхөн байлдан дагуулалтын төлөө байдаг учраас хожмын гэрчлэлийг хийлгэхээр та нарыг сонгох нь хамгийн

зохистой бус уу? Хэрвээ байлдан дагуулалтын ажлын эхний алхам нь хүмүүс та нар дээр хийгдээгүй байсан бол дараагийн байлдан дагуулалтын ажлыг урагш явуулахад хэцүү болох байсан, учир нь дараа болох байлдан дагуулалтын ажил өнөөдөр хийгдэж байгаа энэ ажлын бодит баримтад үндэслэн үр дүнд хүрнэ. Одоогийн байлдан дагуулалтын ажил нь нийт байлдан дагуулалтын ажлын зөвхөн эхлэл юм. Та нар бол байлдан дагуулагдах эхний бүлэг; байлдан дагуулагдах бүх хүн төрөлхтний төлөөлөл юм. Бурханы өнөөдөр хийдэг бүх ажил сайн бөгөөд Бурхан хүмүүст өөрсдийн тэрслүү занг мэдэх боломж олгоод зогсохгүй, бас байр суурийг нь илчилдэг гэдгийг үнэхээр мэдлэгтэй хүмүүс харах болно. Түүний үгийн зорилго, утга учир нь хүмүүсийг гонсойлгохын төлөө байдаггүй, мөн тэднийг унагаахын төлөө ч байдаггүй. Харин Түүний үгээр дамжуулан гэгээрэл, аврал авхуулахын төлөө байдаг; Түүний үгийн замаар тэдний сүнсийг сэрээхийн төлөө байдаг. Дэлхий ертөнц бүтээгдсэн цагаас хойш хүн Бурхан байдаг гэдгийг мэдэхгүйгээр, Бурхан байдаг гэдэгт ч итгэхгүйгээр Сатаны эзэмшил дор амьдарсан. Энэ хүмүүс Бурханы агуу авралд багтаж, Бурханаар асар их өргүүлж байгаа нь үнэндээ Бурханы хайрыг харуулдаг; үнэхээр ойлгодог бүх хүн ингэж бодно. Тийм мэдлэггүй хүмүүс яах вэ? “Ай, Бурхан биднийг Моабын үр удам гэж хэлдэг; Тэр Өөрийн амаар үүнийг хэлсэн. Бид сайн үр дүнд хүрч бас л чадна гэж үү? Бид бол Моабын үр удам, урьд нь бид Бурханыг эсэргүүцэж байсан. Бурхан биднийг яллахаар ирсэн; Тэр бүр эхнээсээ л биднийг үргэлж шүүж байсныг чи харахгүй байна уу? Бид Бурханыг эсэргүүцсэн тул ингэж гэсгээгдэх ёстой” гэж тэд хэлнэ. Эдгээр үг зөв үү? Өнөөдөр Бурхан та нарыг шүүж, гэсгээж, ялладаг боловч чамайг ялладгийн зорилго нь чамд өөрийг чинь мэдүүлэхийн төлөө юм гэдгийг чи мэдэх ёстой. Чамд өөрийг чинь мэдүүлж, зан чанарыг чинь өөрчилж, түүнчлэн үнэ цэнийг чинь мэдүүлж, Бурханы бүх үйлдэл зөвт бөгөөд Бурханы зан чанар, Бурханы ажлын хэрэгцээний дагуу байдаг, Тэр хүнийг аврахын төлөө Өөрийн төлөвлөгөөний дагуу ажилладаг, Тэр бол хүнийг хайрлаж, хүнийг аварч, мөн хүнийг шүүж, гэсгээдэг зөвт Бурхан юм гэдгийг харуулах гэсэндээ Бурхан яллаж, харааж, шүүж, гэсгээдэг. Хэрвээ чи дорд байр суурьтай, завхарсан, дуулгаваргүй гэдгээ л мэддэг боловч өнөөдөр чам дээр хийдэг шүүлт, гэсгээлтээрээ дамжуулан Бурхан Өөрийн авралыг ил болгохыг хүсдэг гэдгийг мэддэггүй бол туршлагажих ямар ч аргагүй бөгөөд цааш үргэлжлүүлж бүр ч чадахгүй. Бурхан хөнөөх юм уу устгахын тулд ирээгүй, харин шүүж, харааж, гэсгээж, аврахын тулд ирсэн юм. Түүний 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөө төгсөх хүртэл—Тэрээр төрөл бүрийн хүний төгсгөлийг илчлэхээс өмнө—газар дээрх Бурханы ажил авралын төлөө байх болно; үүний зорилго нь гагцхүү Өөрийг нь хайрладаг хүмүүсийг бүрмөсөн бүрэн төгс болгож, Өөрийн ноёрхол дор аваачихын төлөө байдаг. Бурхан хүмүүсийг хэрхэн авардаг нь хамаагүй, энэ нь бүхэлдээ, тэднийг хуучин сатанлаг уг чанараас нь салгаснаар хийгддэг; өөрөөр хэлбэл, тэднээр амийг эрж хайлгуулснаар Бурхан тэднийг

авардаг. Хэрвээ тэгэхгүй бол Бурханы авралыг хүлээн авах ямар ч аргагүй байх болно. Аврал бол Бурханы Өөрийн ажил бөгөөд амийг эрэлхийлэх нь аврал хүлээн авахын тулд хүний хийх ёстой зүйл юм. Хүний нүдээр аврал бол Бурханы хайр бөгөөд Бурханы хайр нь гэсгээлт, шүүлт, хараал байж болохгүй; аврал нь хайр, энэрэл, түүнчлэн тайтгарлын үгсийг агуулах ёстой, мөн Бурханы хайрласан хязгааргүй их ерөөлийг агуулах ёстой. Бурхан хүнийг аврах үедээ Өөрийн ерөөл, нигүүлслээр дамжуулан сэтгэлийг нь хөдөлгөдөг болохоор хүмүүс зүрх сэтгэлээ Бурханд өгч чаддаг гэж хүмүүс боддог. Өөрөөр хэлбэл, Тэр хүний сэтгэлийг хөдөлгөж байгаа нь түүнийг аварч байгаа хэрэг юм. Ийм аврал нь наймаацсанаар хийгддэг. Бурхан өөрсдөд нь зуу дахин ихийг өгөх үед л хүн Бурханы нэрийн өмнө захирагдаж, Түүний төлөө сайн ажиллаж, Түүнд алдар суу авчрахаар чармайна. Энэ нь хүн төрөлхтний төлөөх Бурханы санаа зорилго биш юм. Бурхан завхарсан хүн төрөлхтнийг аврахын тулд газар дээр ажиллахаар ирсэн; үүнд ямар ч худал хуурмаг байхгүй. Эс бөгөөс Тэр ажлаа хийхийн тулд биечлэн ирэхгүй байх байсан нь лавтай. Урьд нь Түүний авралын арга барил хамгийн их хайр, энэрлийг харуулж байсан болохоор Тэр бүх хүн төрөлхтний төлөө Өөрт байгаа бүхнээ Сатанд өгсөн юм. Өнөөдөр өнгөрсөн үетэй огт адилгүй: Өнөөдөр та нарт хайрласан аврал эцсийн өдрүүдэд, бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах үед тохиолдож байгаа; та нарыг аврах арга барил хайр юм уу энэрэл биш, харин хүнийг илүү бүрэн дүүрэн аврахын төлөөх гэсгээлт, шүүлт юм. Тиймээс та нарын хүлээн авдаг бүхэн гэсгээлт, шүүлт, өршөөлгүй цохилт байдаг боловч энэ хайр найргүй цохилтод өчүүхэн төдий ч шийтгэл байхгүй гэдгийг мэдэж ав. Миний үг хэчнээн хатуу ширүүн байхаас үл хамааран та нарт тохиолддог зүйл бол ердөө тун хүний үнэргүй санагддаг цөөхөн хэдэн үг бөгөөд Би хэчнээн их уурласан ч бай, та нар дээр буун ирдэг зүйл нь мөн л сургаалын үг бөгөөд Би та нарт хор хөнөөл учруулах гээгүй, эсвэл та нарыг цаазлах гээгүй. Энэ нь бүгд баримт бус уу? Өнөөдөр зөвт шүүлт байсан ч бай, эсвэл хайр найргүй цэвэршүүлэлт, гэсгээлт байсан ч бай, бүгд авралын төлөө байдаг гэдгийг мэдэж ав. Өнөөдөр бүх зүйлийг төрлөөр нь ангилж, эсвэл хүний төрлүүдийг ил болгож байгаа эсэхээс үл хамааран, Бурханы бүх үг болон ажлын зорилго нь Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүсийг аврах явдал юм. Зөвт шүүлт нь хүнийг ариусгахын төлөө, хайр найргүй цэвэршүүлэлт нь хүнийг цэвэрлэхийн төлөө; хатуу үг, эсвэл цээрлүүлэлт нь хоёулаа ариусгаж, аврахын төлөө байдаг. Тиймээс өнөөдрийн авралын арга барил нь өнгөрсөн үеийнхтэй адилгүй. Өнөөдөр зөвт шүүлтээр дамжуулан та нарт аврал ирсэн ба энэ нь та нарыг төрлөөр нь ангилах сайн хэрэгсэл юм. Түүнчлэн, хайр найргүй гэсгээлт нь та нарын дээд зэргийн аврал болдог—энэхүү гэсгээлт, шүүлтийн өмнө та нар юу хэлэх юм бэ? Та нар эхнээсээ дуустлаа үргэлж авралыг эдлээгүй гэж үү? Та нар бие махбодтой болсон Бурханыг харж, Түүний бүхнийг чадагч байдал болон мэргэн ухааныг ухаарсан; үүнээс гадна, удаа дараагийн цохилт, сахилгажуулалтыг туулсан. Гэхдээ та нар бас дээд зэргийн нигүүлслийг

хүртээгүй гэж үү? Та нарын ерөөл өөр хэнийхээс ч илүү их биш гэж үү? Та нарын нигүүлсэл бүр Соломоны эдэлсэн алдар суу болон эд баялгаас илүү элбэг дэлбэг билээ! Энэ талаар бодоод үз: Хэрвээ Миний ирсэн санаа зорилго та нарыг аврахын оронд яллаж, шийтгэхийн төлөө байсан бол өдөр хоногууд чинь ийм удаан үргэлжлэх байсан гэж үү? Мах цустай нүгэлт оршихуй болох та нар өнөөдрийг хүртэл амьд үлдэж чадах байсан уу? Хэрвээ Миний зорилго ердөө та нарыг шийтгэхийн төлөө байсан бол Би яах гэж махбод болж, ийм том ажил үйлс эхлүүлэх юм бэ? Та нар шиг эгэл хүмүүсийг шийтгэхэд ганцхан үг айлдахад л болчих биш үү? Би та нарыг зориуд ялласныхаа дараа мөн л устгах хэрэгтэй юм гэж үү? Та нар Миний энэ үгэнд одоо ч итгэхгүй л байна уу? Би ердөө хайр, энэрлээр л дамжуулан хүнийг аварч чадах юм гэж үү? Эсвэл Би хүнийг аврахын тулд зөвхөн цовдлол ашиглах юм гэж үү? Миний зөвт зан чанар хүнийг бүрмөсөн дуулгавартай болгоход илүү тохиромжтой биш гэж үү? Энэ нь хүнийг бүрэн дүүрэн аварч чадах бус уу?

Би зөвхөн үг хэлж, хүний махан биеийг шийтгэхгүй байгаа болохоор хэдий Миний үг хатуу байж болох ч тэдгээрийг бүгдийг нь хүний авралын төлөө хэлдэг. Эдгээр үг хүнийг гэрэлд амьдруулж, гэрэл оршин байдгийг мэдүүлж, гэрэл бол эрхэм нандин гэдгийг мэдүүлдэг, үүнээс ч илүүтэйгээр эдгээр үг хүнд хэр ач тустайг мэдүүлж, бас Бурхан бол аврал юм гэдгийг мэдүүлдэг. Хэдийгээр Би гэсгээлт, шүүлтийн олон үг хэлсэн боловч тэдгээр нь та нар дээр үнэндээ хийгдээгүй. Би Өөрийн ажлыг хийж, Өөрийн үгийг хэлэхээр ирсэн бөгөөд хэдийгээр Миний үг хатуу чанд байж болох ч та нарын завхрал, тэрслүү байдлыг шүүн тэдгээрийг хэлдэг. Үүнийг хийх Миний зорилго бол хүнийг Сатаны эзэмшлээс аврах явдал хэвээр үлддэг; Би хүнийг аврахын тулд Өөрийн үгийг ашиглаж байгаа; Миний зорилго бол Өөрийн үгээр хүнийг хорлох явдал биш. Өөрийнхөө ажлаар үр дүнд хүрэхийн тулд Миний үг хатуу байдаг. Зөвхөн ийм ажлаар л дамжуулан хүн өөрийгөө мэдэж авч, тэрслүү зан чанараасаа салж чадна. Үгийн ажлын хамгийн их ач холбогдол нь үнэнийг ойлгосныхоо дараа хэрэгжүүлж, зан чанартаа өөрчлөлт гаргаж, өөрсдийнхөө тухай болон Бурханы ажлын тухай мэдлэгтэй болох боломжийг хүмүүст олгох явдал юм. Үг хэлэх арга замаар ажиллах нь л Бурхан, хүн хоёрыг ярилцах боломжтой болгодог бөгөөд үг л үнэнийг тайлбарлаж чадна. Ийм маягаар ажиллах нь хүнийг байлдан дагуулах хамгийн сайн арга барил юм; үг айлдахаас өөр ямар ч арга үнэн болон Бурханы ажлын талаар илүү тодорхой ойлголтыг хүнд өгч чадахгүй. Тиймээс Өөрийнхөө ажлын сүүлчийн үе шатанд Бурхан хүний хараахан ойлгоогүй байгаа бүх үнэн болон нууцыг дэлгэхийн тулд хүнтэй ярьдаг бөгөөд Бурханаас үнэн зам болон амийг олж авч, тэгснээрээ Бурханы хүслийг биелүүлэх боломжийг тэдэнд олгодог. Хүн дээр хийдэг Бурханы ажлын зорилго нь тэдэнд Бурханы хүслийг хангалуун болгох боломж олгохын төлөө байдаг бөгөөд тэдэнд аврал авчрахын тулд хийгддэг. Тиймээс хүнийг аврах хугацаандаа Тэр хүнийг шийтгэх ажил хийдэггүй.

Хүнд аврал авчрах хугацаандаа Бурхан мууг шийтгэж, сайныг шагнадаггүй, мөн бүх төрлийн хүмүүсийн хүрэх газрыг ч илчилдэггүй. Харин ч Өөрийнх нь ажлын эцсийн үе шат гүйцэлдсэний дараа л мууг шийтгэж, сайныг шагнах ажлыг хийх бөгөөд тэр үед л төрөл бүрийн хүмүүсийн төгсгөлийг илчилнэ. Шийтгүүлдэг хүмүүс нь үнэндээ аврагдаж чадахгүй хүмүүс байдаг байхад аврагддаг хүмүүс нь хүнийг аврах авралынх нь хугацаанд Бурханы авралыг хүртсэн хүмүүс байх болно. Бурханы авралын ажил явагдаж байх зуур аврагдаж чадах хүн нэг бүр боломжит дээд хэмжээгээр аврагдах бөгөөд нэг нь ч хаягдахгүй, учир нь Бурханы ажлын зорилго хүнийг аврахын төлөө байдаг. Бурхан хүнийг аврах хугацаанд зан чанартаа өөрчлөлт гаргаж чаддаггүй бүх хүн, түүнчлэн Бурханд бүрэн захирагдаж чаддаггүй бүх хүн шийтгэлийн бай болно. Ажлын энэ үе шат буюу үгийн ажил нь хүмүүст өөрсдийнх нь ойлгодоггүй бүх зам болон нууцыг тайлж өгнө, ингэснээр тэд Бурханы хүслийг болон хүнд тавих Бурханы шаардлагыг ойлгож, улмаар Бурханы үгийг хэрэгжүүлж, зан чанартаа өөрчлөлт гаргах урьдач нөхцөлтэй болж чадна. Бурхан Өөрийн ажлыг хийхдээ зөвхөн үг ашигладаг бөгөөд бага зэрэг тэрслүү байсных нь төлөө хүмүүсийг шийтгэдэггүй; учир нь одоо үе бол авралын ажлын цаг үе билээ. Хэрвээ тэрслүү авирладаг хэн боловч шийтгүүлдэг байсан бол хэн ч аврагдах боломжгүй байх байв; хүн бүр шийтгүүлж, Үхэгсдийн орон руу унах байлаа. Хүнийг шүүдэг үгийн зорилго нь өөрсдийгөө мэдэж, Бурханд захирагдах боломжийг хүнд олгохын төлөө байдаг; харин тэднийг ийм шүүлтээр шийтгэхийн төлөө байдаггүй. Үгийн ажлын хугацаанд олон хүн өөрсдийн тэрслүү байдал, эсэргүүцэл, түүнчлэн бие махбодтой болсон Бурханд хандах дуулгаваргүй байдлыг илчилнэ. Гэхдээ Тэр үүнээс болж энэ бүх хүнийг шийтгэхгүй, харин оронд нь, голдоо хүртэл завхарсан, аврагдах аргагүй хүмүүсийг л хаях болно. Тэр тэдний махан биеийг Сатанд өгч, цөөн хэдэн тохиолдолд махан биеийг нь дуусгавар болгоно. Үлдсэн хүмүүс үргэлжлүүлэн дагаж, харьцалт, засалт туулна. Хэрвээ энэ хүмүүс дагаж байх зууpаа харьцалт, засалтыг хүлээн авч чадахгүй хэвээр байж, улам илүү доройтвол аврагдах боломжоо алдсан байх болно. Бурханы үгийн байлдан дагуулалтыг хүлээн авсан хүн нэг бүр аврагдах асар их боломжтой байх болно; энэ хүмүүсийг нэг бүрчлэн аврахдаа Бурхан дээд зэргийн өршөөл үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, тэдэнд дээд зэргийн хүлээцтэй байдал үзүүлнэ. Хүмүүс буруу замаас буцаж байгаа цагт, мөн гэмшиж байгаа цагт Бурхан тэдэнд Өөрийнх нь авралыг хүртэх боломж олгоно. Хүмүүс эхлээд Бурханы эсрэг тэрслэх үед тэднийг үхүүлэх хүсэл Бурханд байдаггүй; харин ч тэднийг аврахын тулд чадах бүхнээ хийдэг. Хэрвээ хүн үнэхээр аврагдах боломжгүй бол Бурхан тэднийг хаяна. Бурхан аврагдаж чадах хүн бүрийг аврахыг хүсдэг учраас тодорхой хүмүүсийг шийтгэхдээ алгуур байдаг. Тэр зөвхөн үгээр хүмүүсийг шүүж, гэгээрүүлж, залж чиглүүлдэг бөгөөд тэднийг үхүүлэхийн тулд саваа ашигладаггүй. Хүмүүст аврал авчрахын тулд үг ашиглах нь ажлын сүүлчийн үе шатны зорилго, ач холбогдол юм.

ӨӨРИЙН ҮЗЛЭЭР БУРХАНЫГ ХЯЗГААРЛАСАН ХҮН БУРХАНЫ ИЛЧЛЭЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ЯАХАН ЧАДАХ БИЛЭЭ?

Бурханы ажил үргэлж урагшилж байгаа бөгөөд Түүний ажлын зорилго өөрчлөгддөггүй хэдий ч ажилладаг арга барил нь ямагт өөрчлөгдөж, улмаар Бурханыг дагадаг хүмүүс ч бас байнга өөрчлөгдөж байдаг. Бурхан илүү их ажил хийх тусам Бурханы талаарх хүний мэдлэг төдий чинээ бүрэн гүйцэд болдог. Бурханы ажлын үр дүнд хүний зан чанарт ч бас зохих өөрчлөлт гардаг. Гэвч Бурханы ажил үргэлж өөрчлөгдөж байдаг учраас Ариун Сүнсний ажлыг мэддэггүй хүмүүс болон үнэнийг мэддэггүй мулгуу хүмүүс Бурханыг эсэргүүцдэг хүмүүс болдог. Бурханы ажил хэзээ ч хүний үзэлтэй нийцдэггүй, учир нь Бурханы ажил үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй бөгөөд Тэр хуучин ажлыг хэзээ ч давтдаггүй, харин өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийдэг. Бурхан ажлаа давтдаггүй, харин хүн урьдын хийсэн ажилд нь үндэслэн Бурханы одоогийн ажлыг байнга шүүдэг болохоор шинэ эрин үеийн ажлын үе шат болгоныг хэрэгжүүлэхэд Бурханд маш хэцүү байдаг. Хүн хэтэрхий олон бэрхшээлтэй! Бодол санаа нь дэндүү хуучинсаг! Бурханы ажлыг хэн ч мэддэггүй мөртөө хүн бүр үүнийг хязгаарладаг. Бурханаас холдох үедээ хүн амь, үнэн болон Бурханы ерөөлийг алддаг атлаа амийг ч, үнэнийг ч хүлээн зөвшөөрдөггүй, хүн төрөлхтөнд Бурханы хайрладаг илүү агуу ерөөлийг бүр ч хүлээн зөвшөөрдөггүй. Бүх хүн Бурханыг олж авахыг хүсдэг хэр нь Бурханы ажлын ямар ч өөрчлөлтийг тэвчиж чаддаггүй. Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс Бурханы ажил бол хувиршгүй бөгөөд үүрд зогсонги байдалтай байдаг хэмээн итгэдэг. Тэдний бодлоор бол Бурханаас мөнхийн аврал хүртэхийн тулд хуулийг л мөрдөх хэрэгтэй бөгөөд гэмшиж, нүглээ улайж л байвал Бурханы хүсэл үргэлж хангалуун байна. Бурхан бол хуулийн доорх Бурхан, хүний төлөө загалмайд цовдлогдсон Бурхан л байж чадна гэж тэд боддог; тэд бас Бурхан Библиэс хэтрэн гарах ёсгүй, гарч ч чадахгүй гэж боддог. Яг ийм санал бодол нь тэднийг хуучны хуулиудад бат дөнгөлж, үхмэл дүрэм журмуудад хүлсэн юм. Бурханы шинэ ажил ямар ч байлаа гэсэн, зөгнөлөөр баталгаажих ёстой, мөн ийм ажлын үе шат болгонд Түүнийг “чин” сэтгэлээсээ дагадаг бүх хүнд бас илчлэл үзэгдэх ёстой; эс бөгөөс тэр ажил Бурханых байж таарахгүй гэж бүр ч олон хүн боддог. Хүний хувьд Бурханыг мэдэж авах нь угаасаа хялбар ажил биш. Үүнээс гадна, хөгийн зүрх сэтгэл, өөрийгөө чухалчилдаг, ихэрхүү тэрслүү уг чанарыг нь харгалзан үзвэл Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх нь хүний хувьд бүр ч хэцүү билээ. Хүн Бурханы шинэ ажлыг анхааралтай шинжилдэггүй, төлөв даруухнаар хүлээн зөвшөөрдөг ч үгүй; харин ч Бурханы илчлэл болон удирдамжийг хүлээнгээ басамжилсан хандлага баримталж байдаг. Энэ нь Бурханы эсрэг тэрсэлж, эсэргүүцдэг хүмүүсийн зан авир биш гэж үү? Ийм хүмүүс яаж Бурханы сайшаалыг хүртэж чадах юм бэ?

Нигүүлслийн эрин үед Еховагийн ажил хоцрогдсон гэдгийг Есүс хэлж байсны адилаар өнөөдөр Би Есүсийн ажил ч бас хоцрогдсон гэж хэлдэг. Зөвхөн Хуулийн эрин үе гэж байгаад Нигүүлслийн эрин үе байгаагүй бол Есүс цовдлогдохгүй, бүх хүн төрөлхтнийг золин аварч чадахгүй байх байсан юм. Хэрвээ Хуулийн эрин үе л байсан бол хүн төрөлхтөн өнөөдрийг хүрч ер нь чадах байсан гэж үү? Түүх урагшилдаг, түүх бол Бурханы ажлын байгалийн хууль биш гэж үү? Энэ нь бүхий л орчлон ертөнц даяар хүнийг удирдах Түүний удирдлагын дүрслэл биш гэж үү? Түүх урагшилдаг бөгөөд Бурханы ажил ч мөн адил. Бурханы хүсэл тасралтгүй өөрчлөгдөж байдаг. Тэрээр зургаан мянган жилийн турш ажлын ганц үе шатанд үлдэж болохгүй, учир нь хүн бүрийн мэддэгчлэн Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй бөгөөд цовдлолтой адил ажлыг хийсээр байж, загалмайд нэг, хоёр, гурван удаа … цовдлогдох боломжгүй. Ингэж бодох нь тэнэг хэрэг болно. Бурхан нэг ажлыг үргэлжлүүлэн хийдэггүй; Би та нарт өдөр бүр шинэ үг хэлж, шинэ ажил хийдгийн адилаар Түүний ажил ямагт өөрчлөгдөж, үргэлж шинэ байдаг. Энэ бол Миний хийдэг ажил бөгөөд гол түлхүүр нь “шинэ”, “гайхалтай” хэмээх үг юм. “Бурхан хувиршгүй, Бурхан үргэлж Бурхан байх болно” хэмээх үг яах аргагүй үнэн; Бурханы мөн чанар өөрчлөгддөггүй, Бурхан үргэлж Бурхан бөгөөд хэзээ ч Сатан болж чадахгүй боловч Түүний ажил мөн чанартай нь адил тогтмол, хувиршгүй гэдгийг энэ нь нотолдоггүй. Бурхан хувиршгүй гэж чи тунхагладаг, тэгвэл Бурханы үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүйг чи яаж тайлбарлаж чадах юм бэ? Бурханы ажил тасралтгүй түгж, байнга өөрчлөгддөг ба Бурханы хүсэл тасралтгүй илэрхийлэгдэж, хүнд мэдэгдэж байдаг. Бурханы ажлыг туулахын хэрээр хүний зан чанар зогсолтгүй өөрчлөгддөг, мэдлэг нь ч мөн адил. Тэгвэл энэхүү өөрчлөлт хаанаас гардаг юм бэ? Бурханы үргэлж өөрчлөгддөг ажлаас үүддэг биш үү? Хүний зан чанар өөрчлөгдөж болдог юм бол Миний ажил, үг ч бас тасралтгүй өөрчлөгдөхийг хүн яагаад зөвшөөрч чаддаггүй юм бэ? Би хүний хязгаарлалтад захирагдах ёстой гэж үү? Чи хүчээр тулгасан маргаан, мушгин гуйвуулсан логик ашиглаж байгаа бус уу?

Дахин амилсныхаа дараа Есүс шавь нартаа харагдаж, “Та бүхэнд Эцэгийнхээ амлалтыг илгээж буй. Та бүхэн дээрээс ирэх хүчийг хүлээн авах хүртэл Иерусалим хотод үлд” хэмээн хэлсэн. Эдгээр үгийг хэрхэн тайлбарлаж болохыг чи мэдэх үү? Чи одоо Түүний хүч чадлыг хүртсэн үү? “Хүч чадал” гэж юуг хэлдгийг чи ойлгож байна уу? Эцсийн өдрүүдэд үнэний Сүнсийг хүнд хайрлах болно гэж Есүс тунхагласан. Одоо үе бол эцсийн өдрүүд; үнэний Сүнс хэрхэн үг илэрхийлдгийг чи ойлгодог уу? Үнэний Сүнс хаана гарч ирж, ажилладаг вэ? Эш үзүүлэгч Исаиагийн зөгнөлийн номд Есүс нэртэй хүүхэд Шинэ Гэрээний эрин үед төрнө гэж ерөөсөө дурдаагүй; ердөө Иммануел нэртэй нярай хүү төрнө гэж л бичигдсэн. Яагаад “Есүс” гэдэг нэр дурдагдаагүй вэ? Хуучин Гэрээний хаана ч энэ нэр гардаггүй, тэгвэл чи яагаад Есүст итгэсээр байдаг юм бэ? Есүсийг хоёр нүдээрээ харсныхаа дараа л итгэж эхлээгүй чинь лавтай биз дээ? Эсвэл чи илчлэл хүлээн аваад итгэж эхэлсэн

юм уу? Бурхан чамд үнэхээр ийм нигүүлсэл үзүүлнэ гэж үү? Тэгээд чамд ийм агуу ерөөл хайрлана гэж үү? Чи юунд үндэслэн Есүст итгэсэн бэ? Бурхан өнөөдөр махбод болсон гэдэгт яагаад итгэдэггүй юм бэ? Бурханаас чамд илчлэл ирээгүй гэдэг нь Бурхан бие махбодтой болоогүй гэдгийг нотолдог гэж чи яагаад хэлдэг юм бэ? Бурхан Өөрийн ажлыг эхлэхийн өмнө хүмүүст мэдэгдэх ёстой гэж үү? Эхлээд тэдний зөвшөөрлийг авах ёстой гэж үү? Исаиа тэжээлийн онгоцонд эрэгтэй хүүхэд төрнө гэдгийг л тунхагласан; харин Мариа Есүсийг төрүүлнэ гэж хэзээ ч зөгнөөгүй юм. Тэгвэл чи яг юунд үндэслээд Мариагийн төрүүлсэн Есүст итгэдэг юм бэ? Итгэл чинь будилж төөрөлдсөн биш л байлтай? Бурханы нэр өөрчлөгддөггүй гэж зарим нь хэлдэг. Тэгвэл Еховагийн нэр яагаад Есүс болсон юм бэ? Мессиа ирнэ гэж зөгнөсөн атал яагаад Есүс гэдэг нэртэй хүн ирсэн юм бэ? Бурханы нэр яагаад өөрчлөгдсөн бэ? Ийм ажил аль эрт хийгдээгүй гэж үү? Бурхан өнөөдөр илүү шинэлэг ажил хийж болохгүй гэж үү? Өчигдрийн ажил ч өөрчлөгдөж болох бөгөөд Еховагийн ажлыг Есүсийн ажил үргэлжлүүлж болно. Тэгвэл Есүсийн ажлыг өөр нэг ажил залгамжилж болохгүй гэж үү? Хэрвээ Еховагийн нэр Есүс болж өөрчлөгдөж болдог юм бол Есүсийн нэр ч бас өөрчлөгдөж болохгүй гэж үү? Энэ нь хачин жигтэй зүйл биш; ердөө хүмүүс л дэндүү бодлогогүй. Бурхан үргэлж Бурхан байх болно. Түүний ажил болон Түүний нэр яаж ч өөрчлөгдсөн бай, зан чанар, мэргэн ухаан нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэрвээ чи, Бурханыг зөвхөн Есүсийн нэрээр л нэрлэж болно гэж боддог бол мэдлэг чинь хэтэрхий хязгаарлагдмал юм байна. Есүс гэдэг нь үүрд Бурханы нэр байна, Бурхан үргэлж, үүрд Есүс гэх нэртэй байна, энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж чи баталж зүрхлэх үү? Есүсийн нэр Хуулийн эрин үеийг дуусгасан бөгөөд сүүлчийн эрин үеийг ч бас дуусгана гэж чи итгэлтэйгээр баталж зүрхлэх үү? Есүсийн нигүүлсэл эрин үеийг дуусгаж чадна гэж хэн хэлж чадах юм бэ? Чи эдгээр үнэнийг тодорхой ойлгодоггүй бол сайн мэдээг номлож чадахгүйгээр үл барам, өөрөө ч бат зогсож чадахгүй. Чи шашны тэр хүмүүсийн бүх бэрхшээлийг шийдвэрлэж, бүх төөрөгдлийг нь няцаах өдөр ирвэл ажлын энэ үе шатны талаар туйлын их итгэлтэй бөгөөд өчүүхэн ч эргэлзээ тээдэггүй гэдгийг чинь энэ нь нотолно. Хэрвээ чи төөрөгдлийг нь няцааж чадахгүй бол тэд чамайг зохиомлоор буруутгаж, гүжирдэнэ. Энэ нь гутамшигтай байх бус уу?

Иудейчүүд бүгд Хуучин Гэрээг уншсан бөгөөд эрэгтэй хүүхэд тэжээлийн онгоцонд төрнө гэх Исаиагийн зөгнөлийг мэддэг байсан. Тэгвэл энэ зөгнөлийг бүрэн мэддэг байсан мөртөө тэд яагаад Есүсийг мөн л хяхаж хавчсан юм бэ? Энэ нь тэдний тэрслүү уг чанар болон Ариун Сүнсний ажлыг мэддэггүйгээс нь болоогүй гэж үү? Тухайн үед фарисайчууд, зөгнөгдсөн эрэгтэй хүүхдийн талаар өөрсдийнх нь мэддэг зүйлээс Есүсийн ажил өөр байна гэж бодсон; харин бие махбодтой болсон Бурханы ажил Библитэй нийцдэггүй учраас өнөөдрийн хүмүүс Бурханыг голдог. Бурханд хандах тэдний тэрслүү байдлын мөн чанар адилхан биш гэж үү? Чи Ариун Сүнсний бүх ажлыг эргэлзээгүй хүлээн зөвшөөрч чадах уу? Хэрвээ энэ нь Ариун Сүнсний ажил бол зөв урсгал мөн бөгөөд чи ямар ч болгоомжлолгүйгээр

хүлээн зөвшөөрөх ёстой; чи юуг нь хүлээн зөвшөөрөхөө шилж сонгох ёсгүй. Хэрвээ чи Бурханыг илүү гүнзгий ойлгож, Түүнд илүү болгоомжтой ханддаг бол ингэх чинь шаардлагагүй бус уу? Чи Библиэс нэмэлт баталгаа хайх хэрэггүй; хэрвээ энэ нь Ариун Сүнсний ажил мөн бол хүлээн зөвшөөрөх ёстой, учир нь чи дагахын тулд Бурханд итгэдэг бөгөөд Түүнийг судалж шинжлэх ёсгүй. Би бол чиний Бурхан мөн гэдгийг нотлох нэмэлт нотолгоог чи хайх ёсгүй, харин Би чамд ашиг тустай эсэхийг ялган таньж чаддаг байх учиртай—хамгийн чухал зүйл бол энэ юм. Чи Библийн дотроос маргашгүй нотолгоо ихийг оллоо ч гэсэн энэ нь чамайг Миний өмнө бүрэн дүүрэн авчирч чадахгүй. Чи Миний өмнө биш, ердөө Библийн хязгаарлалт дотор л амьдардаг; Библи Намайг мэдэхэд чинь тусалж чадахгүй, Намайг гэх хайрыг чинь ч гүнзгийрүүлж чадахгүй. Эрэгтэй хүүхэд төрнө гэж Библид зөгнөсөн ч Бурханы ажлыг хүн мэддэггүй тул уг зөгнөл хэн дээр биелэхийг хэн ч ухан ойлгож чадаагүй, үүнээс үүдэн фарисайчууд Есүсийн эсрэг зогссон юм. Миний ажил хүний ашиг сонирхлын төлөө байдаг гэдгийг зарим нь мэддэг атлаа Есүс бид хоёрыг харилцан үл нийцэх, бүрмөсөн салангид хоёр оршихуй гэж бодсоор байдаг. Тухайн үед Есүс хэрхэн хэрэгжүүлэх, хэрхэн цугларах, залбирлаараа хэрхэн гуйх, бусдад хэрхэн хандах гэх мэт сэдэвтэй хэдэн цуврал сургаалыг л Нигүүлслийн эрин үед шавь нартаа айлдсан. Түүний гүйцэтгэсэн ажил нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан бөгөөд шавь нар нь болон Өөрийг нь дагадаг хүмүүс хэрхэн хэрэгжүүлэх учиртай талаар л Тэр нарийвчлан тайлбарласан. Тэрээр Нигүүлслийн эрин үеийн ажлыг л хийсэн ба эцсийн өдрүүдийн нэг ч ажлыг хийгээгүй юм. Ехова Хуулийн эрин үед Хуучин Гэрээний хуулийг тогтоох үедээ яагаад Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийгээгүй юм бэ? Яагаад Тэр Нигүүлслийн эрин үеийн ажлыг урьдчилан тодорхой болгоогүй юм бэ? Хүн хүлээн зөвшөөрөхөд энэ нь тус болох байсан биш үү? Тэрээр эрэгтэй хүүхэд төрж, эрх мэдэлд хүрнэ гэдгийг л зөгнөсөн болохоос Нигүүлслийн эрин үеийн ажлыг урьдчилан гүйцэтгээгүй юм. Эрин үе бүр дэх Бурханы ажил тодорхой хил хязгаартай байдаг; Тэр тухайн эрин үеийнхээ ажлыг л хийдэг бөгөөд ажлын дараагийн үе шатыг хэзээ ч урьдчилан гүйцэтгэдэггүй. Энэ маягаар л эрин үе болгон дахь Түүний бэлгэдлийн ажил илүү товойн гарч чаддаг. Есүс зөвхөн эцсийн өдрүүдийн тэмдгүүдийн талаар, хэрхэн тэвчээртэй байж, хэрхэн аврагдах тухай, хэрхэн гэмшиж, нүглээ улайх, мөн хэрхэн загалмай үүрч, зовлонг тэвчих талаар л ярьсан; Тэрээр, эцсийн өдрүүдийн хүн хэрхэн орох ёстой, Бурханы хүслийг хангахын тулд хэрхэн эрж хайх ёстой талаар хэзээ ч яриагүй. Ийм байхад Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг Библиэс хайх нь утгагүй биш үү? Зүгээр л Библитэй зууралдсанаар чи юу харж чадах юм бэ? Библи тайлбарлагч ч бай, номлогч ч бай, өнөөдрийн ажлыг хэн урьдчилан харж чадах юм бэ?

“Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун.” Та нар одоо Ариун Сүнсний үгийг сонсов уу? Бурханы үг та нар дээр ирсэн. Та нар сонсож байна уу? Бурхан эцсийн өдрүүдэд үгийн ажил хийдэг бөгөөд ийм үг нь Ариун Сүнсний үг юм, учир нь Бурхан бол Ариун Сүнс бөгөөд бас махбод ч болж чадна; тиймээс урьд

нь ярьж байсан Ариун Сүнсний үг бол өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы үг юм. Ариун Сүнс ярьж байгаа тул Түүний дуу хоолой тэнгэрээс дуугарч, хүнд сонсогдох ёстой гэж боддог мулгуу хүн олон бий. Ингэж боддог хэн боловч Бурханы ажлыг мэддэггүй. Үнэн хэрэгтээ, Ариун Сүнсний айлдсан айлдварууд нь махбод болсон Бурханы хэлсэн зүйл юм. Ариун Сүнс хүнтэй шууд ярьж чадахгүй; Хуулийн эрин үед ч гэсэн Ехова хүмүүстэй шууд яриагүй. Өнөөдрийн энэ эрин үед Түүний тэгж ярих магадлал бүр ч бага биш үү? Бурхан ажлаа гүйцэтгэхийн тулд айлдвар айлддаг учраас махбод болох ёстой, эс бөгөөс Түүний ажил зорилгоо биелүүлж чадахгүй. Бие махбодтой болсон Бурханыг үгүйсгэдэг хүмүүс бол Сүнсийг юм уу Бурханы ажилладаг зарчмыг мэддэггүй хүмүүс юм. Одоо үе бол Ариун Сүнсний эрин үе гэж боддог атлаа Түүний шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс бол тодорхойгүй, хийсвэр итгэл дунд амьдардаг хүмүүс юм. Ийм хүмүүс Ариун Сүнсний ажлыг хэзээ ч хүлээн авахгүй. Шууд ярьж, ажлаа гүйцэтгэхийг л Ариун Сүнснээс хүсдэг бөгөөд бие махбодтой болсон Бурханы үг болон ажлыг хүлээн авдаггүй хүмүүс шинэ эрин үед хөл тавьж, Бурханы бүрэн авралыг хүртэж хэзээ ч чадахгүй!

БУРХАНЫГ БОЛОН БУРХАНЫ АЖЛЫГ МЭДДЭГ ХҮМҮҮС Л ТҮҮНИЙГ СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙЛГАЖ ЧАДНА

Бие махбодтой болсон Бурханы ажил хоёр хэсгээс бүрддэг. Эхний удаа бие махбодтой болоход нь хүмүүс Түүнд итгээгүй, Түүнийг мэдээгүй ба Есүсийг загалмайд цовдолсон. Хоёр дахь удаад ч гэсэн хүмүүс Түүнийг мэдэх нь байтугай, Түүнд итгээ ч үгүй ба Христийг дахин нэг удаа загалмайд цовдолсон. Хүн Бурханы дайсан биш гэж үү? Бурханыг мэддэггүй бол хүн яаж Түүний дотнын нэгэн байж чадах юм бэ? Бурханд гэрчлэл хийх шаардлагыг яаж хангах юм бэ? Хүн Бурханыг хайрлаж, Бурханд үйлчилж, Бурханыг алдаршуулж байна гэж хэлдэг нь бүгд зальжин худал үг биш гэж үү? Хэрэв чи амьдралаа эдгээр бодит бус, практик бус зүйлсэд зориулах юм бол чиний хөдөлмөр талаар өнгөрөх бус уу? Бурхан хэн бэ гэдгийг ч мэдэхгүй байж чи яаж Бурханы дотнын нэгэн байж чадах юм бэ? Иймэрхүү эрэл хайгуул чинь тодорхойгүй, хийсвэр биш гэж үү? Ов мэхтэй хэрэг бус уу? Хүн хэрхэн Бурханы дотнын нэгэн болох вэ? Бурханы дотнын нэгэн байхын бодит ач холбогдол юу вэ? Чи Бурханы Сүнсний дотнын нэгэн байж чадах уу? Сүнс хэчнээн агуу, өргөмжит болохыг чи харж чадах уу? Үл үзэгдэх, биет бус Бурханы дотнын нэгэн байна гэдэг тодорхойгүй, хийсвэр зүйл биш үү? Ийм эрэл хайгуулд ямар бодит ач холбогдол байна вэ? Энэ нь бүгд худал, хуурмаг биш гэж үү? Чи Бурханыг мэддэггүй бөгөөд нүдэнд үзэгдэж, гарт баригддаггүй, өөрийнхөө үзлээр бий болгосон, оршин байдаггүй “бүх зүйлийн Бурханыг” эрэлхийлдэг учраас чиний эрж хайдаг зүйл Бурханы дотнын хүн болох явдал боловч яг үнэндээ чи Сатаны

бууны нохой юм. Тойруулж хэлбэл, тийм “Бурхан” бол Сатан юм, харин шулуухан хэлбэл энэ нь чи өөрөө юм. Чи өөрийнхөө л дотнын нэгэн байхыг эрэлхийлдэг хэр нь Бурханы дотнын хүн байхаар эрэлхийлж байна гэж хэлдэг—энэ чинь доромжлол биш үү? Ийм эрэл хайгуул ямар үнэ цэнтэй юм бэ? Хэрвээ Бурханы Сүнс махбод болохгүй бол Бурханы мөн чанар нь хүний хувьд хэлбэргүй агаад дүрсгүй, материаллаг бус төрлийн, ойртохын аргагүй хийгээд ойлгогдошгүй, үл үзэгдэх, үл мэдрэгдэх нэгэн амийн Сүнс төдий юм. Хүн ийм материаллаг бус, гайхмаар, ойлгошгүй Сүнсний ойр дотно нэгэн байж яаж чадах юм бэ? Энэ чинь инээдтэй хэрэг биш үү? Тийм утгагүй бодол нь бодит бус, үндэслэлгүй юм. Бүтээгдсэн хүн угаасаа Бурханы Сүнснээс өөр төрлийнх байхад энэ хоёр яаж бие биетэйгээ ойр дотно байж чадах юм бэ? Хэрвээ Бурханы Сүнс махбодод биеллээ олоогүй бол, өөрөөр хэлбэл, Бурхан махбод болоогүй, бүтээл болж, Өөрийгөө даруу болгоогүй бол бүтээгдсэн хүн Түүний дотнын нэгэн байх эрхгүй, бас байж чадах ч үгүй байсан бөгөөд сүнс нь тэнгэрт орсны дараа Бурханы дотнын нэгэн болох боломжтой үнэн сүсэгт итгэгчдээс бусад ихэнх хүн Бурханы Сүнсний дотнын нэгэн болж чадахгүй байх байв. Хэрвээ хүн бие махбодтой болсон Бурханы удирдамж дор тэнгэр дэх Бурханы дотнын нэгэн болохыг хүсдэг бол тэд гайхмаар тэнэг, хүн-бус биш гэж үү? Хүмүүс ердөө л үл үзэгдэх Бурханд “үнэнч байхыг” зорьдог ба харж болох Бурханд өчүүхэн ч анхаарал хандуулдаггүй, учир нь үл үзэгдэх Бурханыг эрэлхийлэх маш амархан. Хүн үүнийг хүссэнээрээ хийж болно. Харин үзэгдэх Бурханыг эрж хайх нь тийм ч амаргүй. Тодорхойгүй Бурханыг эрж хайдаг хүн Бурханыг олж авч огт чадахгүй, учир нь тодорхойгүй, хийсвэр зүйлс нь бүгд хүний төсөөлөл бөгөөд хүний олж авах боломжтой зүйл биш юм. Хэрвээ та нарын дунд ирсэн Бурхан өндөр дээд, өргөмжит агаад чиний ойртохын аргагүй нэгэн байсан бол Түүний хүслийг та нар хэрхэн ойлгож ухаарч чадах юм бэ? Түүнийг яаж мэдэж, ойлгож чадах юм бэ? Хэрвээ Тэр ажлаа л хийгээд, хүнтэй ямар ч хэвийн харилцаа үүсгэдэггүй байсан бол, эсвэл ямар ч хэвийн хүн чанаргүй, жирийн хүмүүс ойртох аргагүй нэгэн байсан бол, тэгээд хэдийгээр Тэр та нарын төлөө их ажил хийсэн ч, та нар Түүнтэй огт харилцдаггүй, Түүнийг харж чаддаггүй байсан бол та нар яаж Түүнийг мэдэж чадах билээ? Хэвийн хүн чанарыг эзэмшсэн энэ махбод байгаагүй сэн бол хүн Бурханыг мэдэх ямар ч аргагүй байх байлаа; Бурхан бие махбодтой болсны хүчинд л хүн махбод дахь Бурханы дотнын нэгэн байх эрхтэй болдог. Хүмүүс Бурхантай харилцдаг болж, Түүнтэй хамт амьдарч, цагийг хамт өнгөрөөснөөр аажмаар Түүнийг мэдэж эхэлдэг учраас Бурханы дотнын хүн болдог. Ингээгүй бол хүний эрэл хайгуул талаар өнгөрөх байсан бус уу? Өөрөөр хэлбэл, дан ганц Бурханы ажлын хүчинд биш, харин бие махбодтой болсон Бурханы бодитой, хэвийн байдлын хүчинд хүн Бурханы дотнын хүн болж чаддаг. Бурхан бие махбодтой болсон учраас л хүн үүргээ биелүүлэх, мөн жинхэнэ Бурханыг шүтэн мөргөх боломжтой болсон билээ. Энэ нь хамгийн бодит, жинхэнэ үнэн биш гэж үү? Чи одоо ч гэсэн тэнгэр дэх Бурханы дотнын нэгэн баймаар байна уу? Бурхан Өөрийгөө

тодорхой түвшинд хүртэл даруу болгосноор буюу махбод болсноор л хүн Түүний дотнын, итгэлт нэгэн болж чадна. Бурхан бол Сүнс: Туйлын өргөмжит, ойлгохын аргагүй энэхүү Сүнсний дотнын хүн байхад хүн яаж тэнцэх юм бэ? Бурханы Сүнс махбодод буун ирж, хүнтэй адил гадаад төрхтэй бүтээл болсноор л хүн Түүний хүслийг ойлгож, Түүгээр үнэхээр авхуулж чадна. Тэр махбодоор үг хэлж, ажиллаж, хүний баяр баясгалан, уйтгар гуниг, гай зовлонг хуваалцаж, хүнтэй нэг дэлхийд амьдарч, хүнийг хамгаалж, залж чиглүүлдэг ба үүгээрээ дамжуулан хүнийг цэвэрлэж, Түүний аврал болон ерөөлийг олж авах боломжийг хүнд олгодог. Хүн эдгээр зүйлийг олж авч, Бурханы хүслийг үнэхээр ойлгосноор л Бурханы дотнын нэгэн байж чаддаг, энэ л бодитой. Хэрвээ Бурхан хүнд үзэгддэггүй, баригддаггүй байсан бол хүн яаж Түүний дотнын нэгэн байж чадах юм бэ? Энэ чинь хоосон сургаал бус уу?

Өнөөдрийг хүртэл Бурханд итгэчхээд олон хүн тодорхойгүй, хийсвэр зүйлийг эрж хайсаар л байна. Тэд Бурханы өнөөгийн ажлын бодит байдлыг огт ухааралгүйгээр одоо ч бичиг үсэг, хоосон сургаал дунд амьдарсаар байдаг. Түүнчлэн ихэнх нь “Бурханыг хайрладаг шинэ үеийнхэн”, “Бурханы дотнын хүн”, “Бурханыг хайрлах үлгэр жишээ, үлгэр дуурайл”, “Петрийн хэв маяг” гэх мэт шинэ хэллэгүүдийн бодит байдал руу хараахан ороогүй байгаа; харин эрэл хайгуул нь тодорхойгүй, хийсвэр хэвээр, хоосон сургаал дунд тэмтэчсээр байгаа бөгөөд тэд эдгээр үгийн бодит байдлын тухай ямар ч ойлголтгүй байдаг юм. Бурханы Сүнс махбод болох үед чи Түүний махбод дахь ажлыг харж, хүрч болно. Гэсэн ч чи Түүний дотнын нэгэн болох чадваргүй хэвээр, Түүний итгэлт анд болж чадахгүй хэвээр байвал хэрхэн Бурханы Сүнсний итгэлт нэгэн болж чадах юм бэ? Хэрвээ чи өнөөдрийн Бурханыг мэдэхгүй бол Бурханыг хайрладаг шинэ үеийнхний нэг болж яаж чадах юм бэ? Эдгээр хэллэг нь зүгээр л хоосон бичиг үсэг, сургаал бус уу? Чи Сүнсийг харж, Түүний хүслийг ухаарч чаддаг уу? Эдгээр хэллэг нь хоосон үг бус уу? Чи зүгээр л эдгээр хэллэг, нэр томьёог ярилаа гээд хангалтгүй, бас чи зөвхөн шийдэмгий байдлаар Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахгүй. Эдгээр үгийг ярих төдийд л сэтгэл чинь ханадаг бөгөөд энэ нь өөрийн чинь хүсэл, бодит бус уран сэтгэмж, үзэл, бодлыг хангахын төлөө л байдаг. Хэрвээ чи өнөөдрийн Бурханыг мэдэхгүй бол юу ч хийлээ гэсэн, Бурханы чин зүрхний хүслийг хангаж чадахгүй. Бурханы итгэлт анд байна гэдэг юу гэсэн үг вэ? Чи үүнийг ойлгохгүй л байна уу? Бурханы дотнын нэгэн бол хүн учраас Бурхан ч гэсэн хүн, өөрөөр хэлбэл, Бурхан махбод болж, хүн болсон. Ижил төрлийн хүмүүс л бие биеэ итгэлт анд гэж дуудаж чадна, тэр үед л тэднийг ойр дотно хүмүүст тооцож болно. Хэрвээ Бурхан Сүнс байсан бол бүтээгдсэн хүн яаж Түүний дотнын нэгэн болж чадах юм бэ?

Бурханд итгэх итгэл, үнэний эрэл хайгуул, тэр ч байтугай биеэ авч яваа байдал чинь бүгд бодит байдалд үндэслэх ёстой: Хийдэг бүхэн чинь бодит байх ёстой, чи хий хоосон, уран зөгнөлт зүйлийг эрэлхийлэх ёсгүй. Ингэж авирлах нь ямар ч үнэ цэнгүй, цаашлаад тийм амьдралд утга учир гэж үгүй. Эрэл хайгуул болон амьдрал

чинь худал хуурмаг, ов мэхнээс цаашгүй зүйлсийн дунд өнгөрч, чи үнэ цэнтэй, ач холбогдолтой зүйлсийг эрж хайдаггүй учраас чиний олж авдаг цорын ганц зүйл бол үнэнтэй хамаагүй утгагүй бодол, хоосон сургаал л байдаг. Тиймэрхүү зүйлс нь чиний оршин тогтнолын үнэ цэн, утга учиртай ямар ч холбоогүй бөгөөд чамайг зөвхөн хоосон газар л аваачиж чадна. Ингэснээр чиний бүхий л амьдрал ямар ч үнэ цэн, утга учиргүй байх болно—хэрвээ чи утга учиртай амьдралыг эрж хайхгүй юм бол зуун жил амьдарлаа ч гэсэн бүгд хий дэмий байх болно. Үүнийг яаж хүний амьдрал гэж хэлж болох юм бэ? Энэ чинь үнэндээ амьтны амьдрал биш үү? Үүний адилаар, хэрвээ та нар Бурханд итгэх замыг дагах гэж хичээдэг боловч харж болох Бурханыг эрж хайх ямар ч оролдлого хийлгүй, оронд нь үл үзэгдэх, биет бус Бурханыг шүтэн мөргөдөг бол иймэрхүү эрэл хайгуул нь бүр ч дэмий биш гэж үү? Эцэстээ чиний эрэл хайгуул нуранги овоо л болох болно. Иймэрхүү эрэл хайгуул чамд ямар ашигтай юм бэ? Хүний хамгийн том бэрхшээл бол өөрийн харж, хүрч чадахгүй, туйлын нууцлаг, гайхалтай зүйлс болон хүмүүсийн төсөөлшгүй, жирийн хүмүүсийн хүрч чадахааргүй зүйлсийг л хайрладаг явдал юм. Эдгээр зүйл хэдий чинээ бодит бус байна, хүн төдий чинээ дүгнэж шинжлэн, бүр бусад бүх зүйлийг умартан эдгээрийг эрж хайж, олж авахаар оролддог. Тэдгээр нь хэдий чинээ бодит бус байна, хүн төдий чинээ нарийвчлан судалж, шинжилдэг төдийгүй тэдгээрийн талаар нарийн нягт бодож сэтгэдэг. Эсрэгээр, хэдий чинээ бодит зүйл байна, хүн төдий чинээ үл тоодог; тэдгээрийг харахдаа хамраа сөхөж, тэр ч байтугай үл тоомсорлодог. Өнөөдөр Миний хийж буй бодит ажилд ханддаг та нарын хандлага яг энэ биш үү? Иймэрхүү зүйлс хэдий чинээ бодитой байна, та нар төдий чинээ сэжиглэдэг. Тэдгээрийг судалж шинжлэх цаг огт гаргалгүй, зүгээр л үл тоодог; эдгээр бодитой, шалгуур султай шаардлагыг та нар басдаг ба тэр ч байтугай хамгийн бодит энэ Бурханы талаар ч гэсэн тоо томшгүй их үзэл өвөрлөдөг бөгөөд зүгээр л Түүний бодит байдал, энгийн байдлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй байдаг. Тэгвэл та нар тодорхойгүй итгэлийг л баримталдаггүй гэж үү? Та нар өнгөрсөн үеийн тодорхойгүй Бурханд тууштай итгээд өнөөгийн бодит Бурханыг сонирхдоггүй. Өчигдрийн Бурхан, өнөөдрийн Бурхан нь хоёр өөр эрин үеийнх болохоор ингэдэг бус уу? Бас өчигдрийн Бурхан нь тэнгэр дэх агуу сүрлэг Бурхан, харин өнөөдрийн Бурхан нь газар дээрх өчүүхэн хүн болохоор ингэдэггүй гэж үү? Түүнчлэн, хүний шүтэн мөргөдөг Бурхан нь түүний үзлээс бий болсон нэгэн, харин өнөөдрийн Бурхан нь газар дээр бий болсон бодит махбод гэдгээс болдоггүй гэж үү? Эцсийн эцэст, өнөөдрийн Бурхан хэтэрхий бодитой учраас хүн Түүнийг эрэлхийлдэггүй бус уу? Учир нь өнөөдрийн Бурханы хүнээс яг тэдний хийх хамгийн дургүй, ичгэвтэр санагддаг зүйлийг нь хүсдэг юм. Энэ нь хүнийг зовоож байгаа хэрэг биш үү? Энэ нь хүний шарх сорвийг ил гаргахгүй гэж үү? Ийм маягаар, олон хүн жинхэнэ Бурхан буюу бодит Бурханыг эрж хайдаггүй тул бие махбодтой болсон Бурханы дайснууд, өөрөөр хэлбэл, антихристүүд болдог. Энэ нь илэрхий баримт биш гэж үү? Өнгөрсөн үед, Бурхан хараахан махбод болоогүй байхад чи шашны

зүтгэлтэн, эсвэл үнэн сүсэгт итгэгч байсан байж болно. Харин Бурхан махбод болсны дараа үнэн сүсэгтэй тэр олон итгэгч өөрсдийн мэдэлгүй антихрист болсон юм. Энд юу болоод байгааг чи мэдэж байна уу? Чи Бурханд итгэхдээ бодит байдалд анхаарлаа төвлөрүүлэн үнэнийг эрж хайхын оронд худал хуурмагт эзэмдүүлдэг. Энэ нь бие махбодтой болсон Бурханы эсрэг дайсагналын чинь хамгийн тодорхой эх үүсвэр бус уу? Бие махбодтой болсон Бурханыг Христ гэж нэрлэдэг, иймээс бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй бүх хүн антихрист бус уу? Тэгэхээр чиний итгэж, хайрладаг нэгэн үнэхээр махбод дахь энэ Бурхан мөн үү? Үнэхээр энэхүү амьдарч, амьсгалж байгаа хамгийн бодит бөгөөд ер бусын энгийн Бурхан мөн үү? Чиний эрэл хайгуулын зорилго яг юу юм бэ? Энэ нь тэнгэрт байгаа юу, газарт байгаа юу? Энэ нь үзэл үү, үнэн үү? Энэ нь Бурхан уу, эсвэл сахиулсан уу? Үнэндээ, үнэн бол амьдралын онч мэргэн үгсээс хамгийн бодитой нь бөгөөд бүх хүн төрөлхтний дундах онч мэргэн үгсээс хамгийн дээд нь билээ. Учир нь энэ бол Бурханы хүнд тавьдаг шаардлага бөгөөд Бурханы биечлэн хийдэг ажил учраас үүнийг амьдралын онч мэргэн үгс гэж нэрлэдэг. Энэ онч мэргэн үг нь ямар нэг зүйлээс дүгнэж гаргасан зүйл биш, мөн агуу хүмүүсийн хэлсэн алдартай эшлэл ч биш; Харин тэнгэр газар, бүх зүйлийн Захирагчаас хүн төрөлхтөнд хэлсэн айлдвар бөгөөд энэ бол хүний нэгтгэн дүгнэсэн хэдэн үг биш, харин Бурханы төрөлх амь билээ. Иймээс үүнийг амьдралын бүх онч мэргэн үгийн хамгийн дээд нь гэж нэрлэдэг. Хүн үнэнийг хэрэгжүүлэхээр эрэлхийлэх нь үүргээ биелүүлж байгаа хэрэг юм, өөрөөр хэлбэл, энэ нь Бурханы шаардлагыг хангах гэсэн эрэл хайгуул юм. Энэхүү шаардлагын мөн чанар нь хэний ч хүрч чадахааргүй хоосон сургаал биш, харин бүх үнэнээс хамгийн бодитой нь юм. Эрэл хайгуул чинь ямар ч бодит байдлыг агуулаагүй хоосон сургаалаас цаашгүй бол чи үнэний эсрэг тэрсэлдэг хүн биш үү? Чи үнэн рүү дайрч довтолдог хүн биш үү? Тийм хүн яаж Бурханыг хайрлахаар эрж хайх юм бэ? Бодит байдалгүй хүмүүс бол бүгд үнэнээс урвадаг хүмүүс бөгөөд угаасаа тэрслүү юм!

Чи яаж ч эрэлхийллээ гэсэн хамаагүй, юун түрүүнд Бурханы өнөөдөр хийж байгаа ажлыг ойлгож, энэхүү ажлын утга учрыг мэдэх ёстой. Бурхан эцсийн өдрүүдэд ирэхдээ ямар ажил, ямар зан чанарыг авчирдаг, мөн хүний юуг бүрэн төгс болгох вэ гэдгийг чи ойлгож, мэдэх ёстой. Махбодод ирээд Түүний хийсэн ажлыг чи мэдэхгүй, ойлгохгүй бол яаж Түүний хүслийг ойлгон ухаарч, Түүний дотнын хүн болж чадах юм бэ? Үнэндээ, Бурханы дотнын нэгэн байна гэдэг нь төвөгтэй зүйл биш боловч амархан хэрэг ч бас биш юм. Хэрвээ хүмүүс нэгд нэггүй ойлгож, хэрэгжүүлж чадвал энэ нь төвөгтэй бус болдог; хэрвээ нэгд нэггүй ойлгож чадахгүй бол энэ нь нэлээд хэцүү болдог төдийгүй эрэл хайгуул нь тэднийг тодорхойгүй байдал руу амархан хөтөлдөг. Хэрвээ хүн Бурханыг эрэлхийлэхдээ өөрийн гэсэн тулгуур байр суурьгүй, ямар үнэнийг баримтлах ёстойгоо мэдэхгүй бол ямар ч үндэс суурьгүй байна гэсэн үг учраас бат зогсоход тэдэнд амаргүй болдог. Өнөөдөр, үнэнийг ойлгодоггүй, сайн мууг ялгадаггүй, хайрлах, үзэн ядахыг хэлж

мэддэггүй маш олон хүн байна. Тийм хүмүүс бат зогсож бараг чадахгүй. Бурханд итгэхийн гол түлхүүр нь үнэнийг хэрэгжүүлж, Бурханы хүслийг анхаарч, Бурхан махбодод ирэх үедээ хүн дээр хийдэг ажил, Түүний үг хэлдэг зарчмыг мэдэж чаддаг байх явдал юм. Олныг бүү дага. Чи орох ёстой зүйлдээ зарчимтай байж, тэдгээрийг баримтлах ёстой. Дотор чинь байгаа Бурханы гэгээрүүлсэн тэдгээр зүйлийг чанд мөрдөх нь чамд тустай. Тэгэхгүй бол чи өнөөдөр нэг чиглэлд, маргааш нөгөө чиглэлд эргэлдэн, бодитой ямар нэг зүйлийг хэзээ ч олж авахгүй. Ийм байх нь чиний аминд ямар ч ашиггүй. Үнэнийг ойлгодоггүй хүмүүс үргэлж бусдыг дагадаг: Хүмүүс үүнийг Ариун Сүнсний ажил гэж хэлэх юм бол чи ч гэсэн Ариун Сүнсний ажил мөн байна гэж хэлнэ; хэрвээ хүмүүс үүнийг муу ёрын сүнсний ажил гэж хэлбэл чи ч гэсэн эргэлзэж эхлэн, эсвэл бас үүнийг муу ёрын сүнсний ажил байна гэж хэлнэ. Чи бусдын үгийг үргэлж тоть шиг давтдаг бөгөөд өөрөө юуг ч ялган салгах чадваргүй, бас өөрийнхөөрөө бодож сэтгэж чаддаггүй. Энэ бол баримтлах байр суурьгүй, ялган салгах чадваргүй хүн бөгөөд ийм хүн бол хэнд ч хэрэггүй хүн юм! Чи дандаа бусдын үгийг давтдаг: Өнөөдөр үүнийг Ариун Сүнсний ажил гэж хэлж байгаа ч нэг өдөр үүнийг Ариун Сүнсний ажил биш, харин хүний үйл хэргээс цаашгүй гэж хэн нэгэн хүн хэлж магадгүй—гэсэн ч чи үүнийг ялган салгаж чадахгүй бөгөөд бусад хүний хэлэхийг сонсоод чи ч бас тэгж хэлнэ. Энэ нь үнэндээ Ариун Сүнсний ажил, гэвч чи үүнийг хүний ажил гэж хэлдэг; чи Ариун Сүнсний ажлыг гутаадаг хүмүүсийн нэг болсон бус уу? Чи ийнхүү ялган салгаж чадахгүй байгаа учраас Бурханыг эсэргүүцсэн бус уу? Хэн мэдэх вэ, магадгүй нэг өдөр “энэ бол муу ёрын сүнсний ажил” гэж хэлэх эргүү амьтан гарч ирж болох юм, тэгвэл чи энэ үгийг сонсонгуутаа яахаа мэдэхээ больж, дахиад л бусдын үгэнд автах болно. Хэн нэгэн чамайг үймүүлэх болгонд чи баримтлах байр сууриндаа бат зогсож чаддаггүй бөгөөд энэ бүхэн үнэнийг эзэмшээгүйгээс чинь л болж байгаа юм. Бурханд итгэж, Бурханы тухай мэдлэгийг эрж хайна гэдэг энгийн зүйл биш. Зүгээр л хамтдаа цугларч, номлол сонссоноор тэдгээрийг олж авч чадахгүй, ганцхан урам зоригоороо чи төгс болгуулж чадахгүй. Чи туулж, мэдэж, үйлдэлдээ зарчимтай байж, Ариун Сүнсний ажлыг олж авах ёстой. Чи туршлагыг туулснаар олон зүйлийг ялган салгаж чадна—сайныг муугаас, зөв шударга байдлыг хорон муу явдлаас ялган салгаж, мөн аль нь мах цусных, аль нь үнэнийх вэ гэдгийг ялгаж чадна. Чи энэ бүх зүйлийг ялган салгаж чаддаг байх ёстой, ингэснээр ямар ч нөхцөлд чи хэзээ ч төөрөхгүй. Энэ л чиний биеийн жинхэнэ хэмжээ юм.

Бурханы ажлыг мэднэ гэдэг энгийн хэрэг биш. Чи эрэл хайгуулдаа стандарт, зорилготой байх ёстой бөгөөд үнэн замыг хэрхэн эрж хайхаа мэддэг, энэ нь үнэн зам мөн эсэх, Бурханы ажил мөн эсэхийг хэрхэн хэмжихээ мэддэг байх ёстой. Үнэн замыг эрж хайх хамгийн үндсэн зарчим юу вэ? Энэ замд Ариун Сүнсний ажил бий эсэх, эдгээр үг нь үнэний илэрхийлэл мөн эсэх, хэнийг гэрчилдэг болох, мөн энэ нь чамд юу авчирч чадах вэ гэдгийг чи харах учиртай. Үнэн зам, хуурамч зам хоёрыг ялгаж салгахад үндсэн мэдлэгийн хэд хэдэн тал шаардлагатай ба үүнээс хамгийн

гол нь Ариун Сүнсний ажил бий эсэхийг харах явдал юм. Учир нь, Бурханд итгэх хүний итгэлийн мөн чанар нь Бурханы Сүнсэнд итгэх итгэл бөгөөд бие махбодтой болсон Бурханд итгэх хүний итгэл ч гэсэн энэхүү махбод нь Бурханы Сүнсний биелэл гэдгээс үүдэлтэй, өөрөөр хэлбэл, тийм итгэл бол мөн л Сүнсэнд итгэх итгэл билээ. Сүнс, махбод хоёр хоорондоо ялгаатай боловч энэхүү махбод нь Сүнснээс ирдэг агаад махбод болсон Үг учраас хүний итгэж байгаа зүйл бас л Бурханы төрөлх мөн чанар юм. Тэгэхээр, үнэн зам мөн эсэхийг ялгахдаа чи юун түрүүнд Ариун Сүнсний ажил байгаа эсэхийг харж, дараа нь энэ замд үнэн байгаа эсэхийг харах ёстой. Үнэн бол хэвийн хүн чанарын амь зан чанар, өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг анх бүтээх үедээ хүнд тавьсан шаардлага буюу бүх хэвийн хүн чанар юм (үүнд хүний эрүүл ухаан, мэдлэг, мэргэн ухаан, хүн байхын үндсэн мэдлэг багтана). Өөрөөр хэлбэл, энэ зам хүнийг хэвийн хүн чанарын амьдрал руу хөтөлж чадах эсэх, ярьсан үнэн нь хэвийн хүн чанарын бодит байдлын дагуу шаардлагатай эсэх, энэ үнэн нь бодитой, жинхэнэ эсэх, цагаа олсон эсэхийг харах хэрэгтэй. Хэрвээ үнэн байгаа бол энэ нь хүнийг хэвийн, бодит туршлага руу аваачиж чадна; түүнчлэн хүн улам хэвийн болж, хүний эрүүл ухаан улам бүрэн төгс болж, хүний махан бие дэх амьдрал болон сүнслэг амьдрал улам эмх цэгцтэй болж, хүний мэдрэмж улам хэвийн болдог. Энэ нь хоёр дахь зарчим юм. Бас нэгэн өөр зарчим байдаг нь, хүний Бурханы талаарх мэдлэг нь өсөн нэмэгддэг эсэх, тийм ажил болон үнэнийг туулах нь хүний дотор Бурханыг хайрлах хайрыг бадраж, Бурхантай улам ойртуулж чаддаг эсэх юм. Үүнээс энэхүү зам нь үнэн зам мөн эсэхийг хэмжиж болно. Хамгийн гол нь, энэ зам ер бусын биш, бодит эсэх, мөн энэ нь хүний амийг хангаж чаддаг эсэх юм. Эдгээр зарчимд нийцэж байвал энэ замыг үнэн зам хэмээн дүгнэж болно. Ирээдүйн туршлагын чинь явцад та нараар өөр замыг хүлээн зөвшөөрүүлж, эсвэл ирээдүйд бас нэгэн шинэ эрин үеийн ажил байх болно гэж зөгнөх гэсэндээ ч Би эдгээр үгийг хэлж байгаа юм биш. Харин өнөөдрийн зам бол үнэн зам мөн гэдэгт та нарыг итгэлтэй байг гэсэндээ, мөн та нарыг өнөөдрийн ажилд зөвхөн хагас хугас итгэж, мэдлэг олж авч чадахгүй бүү байг гэсэндээ Би ингэж хэлдэг. Итгэлтэй байгаа хэр нь будилан дагадаг хүмүүс ч олон байдаг; ийм итгэлтэй байдал нь ямар ч зарчимгүй байдаг ба эрт орой хэзээ нэгэн цагт тэд таягдан хаягдах болно. Дагахдаа маш гал цогтой хүмүүс ч гэсэн гурван хэсэгт нь итгэлтэй, таван хэсэгт нь эргэлзээтэй байдаг ба энэ нь тэдний ямар ч ул суурьгүйг харуулдаг. Та нарын хэв чанар хэтэрхий ядмаг, суурь чинь хэтэрхий өнгөц учраас ялган салгах талаар ямар ч ойлголтгүй байна. Бурхан Өөрийн ажлыг давтдаггүй, бодитой бус ажил хийдэггүй, хүнд хэрээс хэтэрсэн шаардлага тавьдаггүй, бас хүний эрүүл ухаанаас давсан ажил хийдэггүй. Түүний хийдэг бүх ажил хүний хэвийн ухааны хүрээнд байж, хэвийн хүн чанарын эрүүл ухаанаас давдаггүй бөгөөд Түүний ажил хүний хэвийн шаардлагын дагуу байдаг. Хэрвээ Ариун Сүнсний ажил мөн бол хүн улам хэвийн болж, хүн чанар улам хэвийн болдог. Хүн өөрийн ялзарсан сатанлаг зан чанар болон хүний гол чанарын талаар улам их мэдлэгтэй болж, үнэнийг улам ихээр

хүсэн тэмүүлдэг. Өөрөөр хэлбэл, хүний амь улам өсөж, хүний завхарсан зан чанар улам их өөрчлөгдөж чадна—энэ бүхэн нь Бурхан хүний амь болохын уг утга учир юм. Хэрвээ тухайн зам нь хүний гол чанар болох зүйлсийг илчилж, хүний зан чанарыг өөрчилж чадахгүй, түүнчлэн хүнийг Бурханы өмнө аваачиж, Бурханы талаарх үнэн зөв ойлголтыг хүнд өгч чадахгүй, тэр ч байтугай хүн чанарыг нь улам дорд болгож, эрүүл ухааныг нь улам хэвийн бус болгож байвал энэ зам үнэн зам байх учиргүй бөгөөд энэ нь муу ёрын сүнсний ажил юм уу хуучин зам байж болох юм. Товчхондоо гэвэл, энэ нь Ариун Сүнсний өнөөгийн ажил байж таарахгүй. Та нар энэ олон жил Бурханд итгэчхээд үнэн зам, хуурамч замыг ялган салгах, үнэн замыг эрж хайх зарчмын талаар өчүүхэн төдий ч ойлголтгүй байна. Ихэнх хүн эдгээр асуудлыг сонирхдог ч үгүй; тэд ердөө л олонхын явж байгаа зүгт явж, олонхын хэлснийг давтдаг. Энэ яаж үнэн замыг эрж хайж байгаа хүн байх юм бэ? Тийм хүмүүс яаж үнэн замыг олох юм бэ? Хэрвээ чи энэ хэдэн гол зарчмыг ойлгож ухаарах юм бол юу ч боллоо гэсэн хууртахгүй. Өнөөдөр хүн аливааг ялган салгаж чаддаг байх нь амин чухал; энэ нь хэвийн хүн чанарын эзэмшсэн байх ёстой зүйл бөгөөд туршлагадаа хүний эзэмших учиртай зүйл юм. Хэрвээ өнөөдөр ч гэсэн хүмүүс дагах явцдаа юуг ч ялган салгадаггүй, хүний эрүүл ухаан нь одоо ч өсөөгүй л байвал хүмүүс хэтэрхий мунхаг байна, эрэл хайгуул нь ч гэсэн алдаж, ташуурсан байна. Чиний өнөөдрийн эрэл хайгуулд өчүүхэн ч ялгаж салгах явдал алга, чиний хэлдгээр чи үнэн замыг олсон ч гэсэн үүнийгээ олж авсан уу? Ямар нэг зүйлийг ялган салгаж чадаж байгаа юу? Үнэн замын мөн чанар нь юу вэ? Үнэн замд чи үнэн замыг олж аваагүй, үнэнээс юуг ч олж аваагүй. Өөрөөр хэлбэл, Бурханы чамаас шаарддаг зүйлийг биелүүлээгүй, тиймээс чиний завхралд ямар ч өөрчлөлт гараагүй. Хэрвээ чи энэ маягаар эрэлхийлсээр байвал эцэстээ таягдан хаягдах болно. Өнөөдрийг хүртэл дагасан тул чи сонгосон замаа зөв зам гэдэгт итгэлтэй байж, дахин эргэлзэх ёсгүй. Олон хүн байнга эргэлздэг бөгөөд зарим нэг жижиг асуудлаас болж үнэнийг эрэлхийлэхээ больдог. Тийм хүмүүс бол Бурханы ажлын талаар ямар ч мэдлэггүй хүмүүс бөгөөд Бурханыг будилан дагадаг хүмүүс юм. Бурханы ажлыг мэддэггүй хүмүүс Түүний дотнын нэгэн болж, Бурханыг гэрчлэх чадваргүй байдаг. Зөвхөн ерөөл эрж хайж, тодорхойгүй, хийсвэр зүйлийг л эрэлхийлдэг хүмүүст үнэнийг даруйхан эрж хай гэж Би зөвлөе, ингэснээр тэдний амьдрал утга учиртай болно. Өөрсдийгөө цаашид бүү хуур!

БИЕ МАХБОДТОЙ БОЛСОН БУРХАНЫ ҮЙЛЧЛЭЛ БА ХҮНИЙ ҮҮРГИЙН ЯЛГАА

Та нар Бурханы ажлын үзэгдлийг мэдэж авч, Түүний ажлын ерөнхий чиглэлийг ухаарах ёстой. Энэ нь эерэг оролт юм. Үзэгдлийн тухай үнэнийг яг таг эзэмшингүүт оролт чинь найдвартай болно; Бурханы ажил яаж өөрчлөгдөх нь хамаагүй, чи зүрх

сэтгэлдээ тууштай байж, үзэгдлүүдийн талаар тодорхой мэдэж, оролт болон эрэл хайгуул чинь зорилготой болно. Ийм маягаар, чиний доторх бүхий л туршлага, мэдлэг илүү гүнзгийрч, улам нарийсна. Ерөнхий чиг хандлагыг бүхэлд нь ойлгомогц амь чинь ч хохирол амсахгүй, чи ч төөрөлдөхгүй. Хэрвээ чи ажлын эдгээр алхмыг мэдэж авахгүй бол алхам бүрд хохирол амсах бөгөөд хэдхэн өдрийн дотор үүнийг өөрчилж чадахгүй, хоёр долоо хоногийн дотор ч зөв замд орж чадахгүй. Энэ нь саатал учруулахгүй гэж үү? Эерэг оролт болон хэрэгжүүлэлтийн замд та нарын эзэмших ёстой зүйл их байдаг. Бурханы ажлын үзэгдлийн тухайд бол, чи дараах зүйлсийг ухаарах ёстой: Түүний байлдан дагуулалтын ажлын ач холбогдол, төгс болгуулах ирээдүйн зам, шалгалт, гай зовлон туулснаар юунд хүрэх ёстой, шүүлт, гэсгээлтийн утга учир, Ариун Сүнсний ажлын зарчмууд болон төгс болгох, байлдан дагуулах зарчмууд. Эдгээр нь бүгд үзэгдлүүдийн тухай үнэнд харьяалагддаг. Үлдсэн нь Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе, Хаанчлалын эрин үе дэх ажлын гурван үе шат, мөн түүнчлэн ирээдүйн гэрчлэл юм. Эдгээр нь ч бас үзэгдлүүдийн тухай үнэн бөгөөд хамгийн гол, хамгийн чухал нь юм. Одоо та нарын хэрэгжүүлж, орох ёстой зүйл маш их байдаг ба энэ нь одоо илүү олон давхаргатай, илүү дэлгэрэнгүй байдаг. Хэрвээ чамд эдгээр үнэний талаарх мэдлэг байхгүй бол хараахан ороогүй байгааг чинь энэ нь нотолдог. Ихэнхдээ үнэний талаарх хүмүүсийн мэдлэг хэтэрхий өнгөц байдаг; тэд зарим энгийн үнэнийг хэрэгжүүлэх чадваргүй байдаг ба ялихгүй асуудлуудыг ч хэрхэн зохицуулахаа мэддэггүй. Хүмүүс үнэнийг хэрэгжүүлж чаддаггүйн шалтгаан нь тэдний тэрслүү зан чанараас болдог, мөн өнөөдрийн ажлын талаарх мэдлэг нь хэтэрхий өнгөц, өрөөсгөл байдгаас болдог. Тиймээс, хүмүүсийн хувьд төгс болгуулна гэдэг тийм ч амархан ажил биш. Чи дэндүү тэрслүү бөгөөд хуучин байдлаа хэтэрхий их хадгалдаг; үнэний талд зогсох чадваргүй, хамгийн илэрхий үнэнийг ч хэрэгжүүлэх чадваргүй. Ийм хүмүүс аврагдаж чадахгүй бөгөөд байлдан дагуулагдаагүй хүмүүс юм. Хэрвээ чиний оролт нарийн ширийн юмгүй, бас зорилгогүй бол өсөлт чинь удаан байх болно. Хэрвээ чиний оролт өчүүхэн ч бодит байдалгүй бол эрэл хайгуул чинь талаар болно. Хэрвээ чи үнэний мөн чанарыг мэдэхгүй бол өөрчлөгдөөгүй хэвээр үлдэнэ. Хүний амийн өсөлт ба зан чанарын өөрчлөлт нь бодит байдалд орсноор, түүнчлэн нарийвчилсан туршлага руу орсноор явагддаг. Хэрвээ орох үедээ чи олон нарийвчилсан туршлагатай байвал, мөн ихээхэн бодит мэдлэг болон оролттой байвал зан чанар чинь хурдан өөрчлөгдөнө. Одоогоор чи хэрэгжүүлэлтийн талаар тов тодорхой мэдэхгүй байсан ч гэсэн, ядаж л Бурханы ажлын үзэгдлийн талаар тодорхой мэдэж байх ёстой. Эс бөгөөс чи орох чадваргүй байх болно; үнэний мэдлэгтэй болж байж л орох боломжтой. Туршлагыг чинь Ариун Сүнс гэгээрүүлсэн үед л чи үнэний талаар илүү гүнзгий ойлгож, илүү гүн орж чадна. Та нар Бурханы ажлыг мэдэж авах ёстой.

Анх, хүн төрөлхтөн бүтээгдсэний дараа Бурханы ажлын үндэс суурь болон үйлчилж байсан хүмүүс нь израильчууд байв. Израиль бүхэлдээ Еховагийн газар

дээрх ажлын суурь байсан билээ. Еховагийн ажил нь хууль тогтоосноор дамжуулан хүнийг шууд удирдаж, хариулах явдал байсан бөгөөд ингэснээр хүн хэвийн амьдралаар амьдарч, газар дээр хэвийн байдлаар Еховаг шүтэн мөргөж чадах байсан юм. Хуулийн эрин үе дэх Бурханыг хүн харж ч, хүрч ч чадахгүй байлаа. Тэрээр Сатаны завхруулсан анхны хүмүүсийг л удирдан чиглүүлж, тэдэнд зааж сургаж, тэднийг хариулж байсан учраас Түүний үг хууль, тогтоол болон хүний биеэ авч явах стандартыг л агуулж байсан бөгөөд тэдний амийг үнэнээр хангаагүй юм. Түүний удирдлага дор байсан израильчууд Сатаны гүн гүнзгий завхруулсан хүмүүс биш байв. Түүний хуулийн ажил нь ердөө авралын ажлын хамгийн эхний үе шат, авралын ажлын эхлэл байсан ба үнэндээ хүний амь зан чанарын өөрчлөлттэй бараг ямар ч хамаагүй байлаа. Тиймээс, авралын ажлын эхэн үед Израиль дахь ажлынхаа төлөө Тэрээр махбодтой болох хэрэггүй байсан юм. Ийм учраас Түүнд хүнтэй харилцахдаа ашиглах зууч буюу хэрэгсэл шаардлагатай байв. Тиймээс, бүтээгдсэн зүйлсийн дунд Еховагийн өмнөөс ажиллаж, ярьдаг хүмүүс бий болсон бөгөөд ийнхүү хүний хөвгүүд болон эш үзүүлэгчид хүмүүсийн дунд ажиллах болжээ. Хүний хөвгүүд Еховагийн өмнөөс хүмүүсийн дунд ажиллав. Еховагаар “хүний хөвгүүд” гэж дуудагдана гэдэг нь тийм хүмүүс Еховагийн өмнөөс хууль тогтоосон гэсэн үг юм. Тэд бас Израилийн ард түмний дундах тахилчид, Еховагийн харж хандаж, хамгаалж байсан тахилчид байсан бөгөөд Еховагийн Сүнс тэдний дотор ажилладаг байжээ; тэд хүмүүсийн дундах удирдагчид байсан ба Еховад шууд үйлчилж байв. Нөгөөтээгүүр, эш үзүүлэгчид бүх газар нутаг, овгийн хүмүүст Еховагийн өмнөөс ярихад өөрсдийгөө зориулсан хүмүүс байсан юм. Тэд ч бас Еховагийн ажлыг зөгнөж байлаа. Хүний хөвгүүд ч бай, эсвэл эш үзүүлэгчид ч бай, бүгдийг нь Еховагийн Сүнс Өөрөө өргөсөн ба тэдэнд Еховагийн ажил байсан юм. Хүмүүсийн дунд тэд Еховаг шууд төлөөлдөг хүмүүс байсан; тэд Ариун Сүнсний Өөрийн махбод болсон бие байсан учраас биш, харин Ехова өөрсдийг нь өргөсөн учраас л ажлаа хийсэн билээ. Тиймээс, Бурханы өмнөөс ярьж, ажилласнаараа адилхан байсан хэдий ч Хуулийн эрин үе дэх хүний хөвгүүд ба эш үзүүлэгчид нь Бурханы махбод болсон бие байгаагүй юм. Нигүүлслийн эрин үе болон сүүлчийн үе шатан дахь Бурханы ажил яг эсрэгээрээ байсан, учир нь авралын ажил болон хүнийг шүүх шүүлтийг хоёуланг нь бие махбодтой болсон Бурхан Өөрөө хийсэн тул Өөрийнх нь оронд ажиллах хүний хөвгүүд болон эш үзүүлэгчдийг дахин нэгэнтээ өргөх хэрэггүй байв. Хүний нүдээр бол, тэдний ажлын мөн чанар, арга барилын хооронд үндсэн ялгаа байхгүй. Энэ шалтгааны улмаас хүмүүс бие махбодтой болсон Бурханы ажлыг эш үзүүлэгчид болон хүний хөвгүүдийн ажилтай байнга андуурч будилдаг. Бие махбодтой болсон Бурханы харагдах байдал нь үндсэндээ эш үзүүлэгч, хүний хөвгүүдийнхтэй адилхан байсан. Бие махбодтой болсон Бурхан нь эш үзүүлэгчдийг бодвол бүр ч илүү хэвийн, илүү бодитой байв. Тиймээс хүн тэднийг ялгаж чаддаггүй. Хүн гагцхүү харагдах байдалд анхаарлаа төвлөрүүлдэг бөгөөд хэдий хоёулаа адилхан ажиллаж, үг хэлдэг ч тэдний хооронд үндсэн ялгаа

байдаг гэдгийг огт мэддэггүй. Хүний ялган таних чадвар хэтэрхий дульхан байдаг учраас энгийн асуудлуудыг ялган таньж чаддаггүй, нарийн төвөгтэй зүйлийг бол бүр ч чаддаггүй. Эш үзүүлэгчид болон Ариун Сүнсний ашигласан тэр хүмүүс үг хэлж, ажилласан нь бүгд хүний үүргийг биелүүлж, бүтээгдсэн зүйлийн чиг үүргийг гүйцэтгэхийн төлөө байсан бөгөөд энэ нь хүний хийх учиртай зүйл байсан юм. Харин бие махбодтой болсон Бурханы үг ба ажил нь Түүний үйлчлэлийг хэрэгжүүлэхийн төлөө байсан. Түүний гадаад хэлбэр хэдий бүтээгдсэн зүйлийнх байсан ч Түүний ажил нь Өөрийн чиг үүргийг биш, харин Өөрийн үйлчлэлийг биелүүлэхийн төлөө байв. “Үүрэг” гэсэн нэр томьёо нь бүтээгдсэн зүйлтэй холбоотой хэрэглэгддэг байхад “үйлчлэл” нь Бурханы махбод болсон биетэй холбоотойгоор хэрэглэгддэг. Энэ хоёрын хооронд мөн чанарын ялгаа бий; тэдгээр нь харилцан солигддоггүй. Хүний ажил бол зөвхөн үүргээ биелүүлэх явдал байхад Бурханы ажил бол удирдаж, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал юм. Тиймээс, хэдийгээр Ариун Сүнс олон элчийг ашиглаж, олон эш үзүүлэгч Түүгээр дүүргэгдэж байсан ч тэдний ажил ба үг ердөө л бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлэхийн төлөө байв. Тэдний зөгнөл бие махбодтой болсон Бурханы хэлсэн амийн үгээс хэтрэн гарч, хүн чанар нь бие махбодтой болсон Бурханыхаас ч давсан байж болох ч тэд үйлчлэл хийж байсан юм биш, харин үүргээ л биелүүлж байсан билээ. Хүний үүрэг нь хүний чиг үүргийг хэлдэг; энэ нь хүний хүрч болох зүйл юм. Харин, бие махбодтой болсон Бурханы хэрэгжүүлдэг үйлчлэл нь Түүний удирдлагатай холбоотой ба үүнд хүн хүршгүй юм. Бие махбодтой болсон Бурхан ярьж, ажиллаж, гайхамшгийг үзүүлж байсан ч Өөрийн удирдлага дунд агуу ажил хийж байгаа ба тийм ажлыг хүн Түүний оронд хийж чадахгүй. Хүний ажил бол Бурханы удирдлагын ажлын тодорхой үе шатанд, бүтээгдсэн зүйлийн үүргээ л биелүүлэх явдал юм. Бурханы удирдлагагүй бол, өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханы үйлчлэл алдагдсан бол бүтээгдсэн зүйлийн үүрэг ч гэсэн алдагдах байв. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх Бурханы ажил нь хүнийг удирдах явдал байхад хүн үүргээ биелүүлнэ гэдэг нь Бүтээгчийн шаардлагад нийцэхийн тулд үүрэг даалгавраа биелүүлэх явдал бөгөөд үйлчлэлээ хэрэгжүүлж байгаа хэрэг гэж үзэж яавч болохгүй. Бурханы төрөлхийн гол чанарт—Түүний Сүнсэнд—Бурханы ажил бол Өөрийнх нь удирдлага, харин бүтээгдсэн зүйлийн гадаад хэлбэртэй бие махбодтой болсон Бурханы хувьд, Түүний ажил бол Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал юм. Тэр ямар ч ажил хийлээ гэсэн, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж байгаа; хүн Бурханы удирдлагын цар хүрээн дотор, Түүний удирдамж дор чадах бүхнээ хийж л болно.

Хүний үүргийн биелэлт гэдэг нь үнэндээ хүнд угаасаа байсан бүхнийг буюу хүний хувьд төрөлхөөсөө боломжтой зүйлийг биелүүлэх явдал юм. Тэр үед түүний үүрэг биелдэг. Үйлчлэлийн үеэрх хүний дутагдал нь алгуур туршлагаар болон шүүлт туулах үйл явцаар дамжуулан аажмаар багасдаг; тэдгээр нь хүний үүрэгт нөлөөлөх юм уу саад болдоггүй. Үйлчлэлд нь саад тотгор гарч болзошгүй гэж айсандаа үйлчлэхээ больж, бууж өгч, эсвэл ухарч няцдаг хүмүүс бол бүх хүний

дотроос хамгийн хулчгар нь юм. Хэрвээ хүмүүс үйлчлэлийн үеэр өөрсдийн илэрхийлэх ёстой зүйлийг илэрхийлж чадахгүй, эсвэл өөрсдийнх нь хувьд төрөлхөөсөө боломжтой зүйлийг биелүүлж чадахгүй, харин оронд нь аргацааж, хааш яаш хандвал бүтээгдсэн зүйлд байх ёстой чиг үүргээ алджээ. Тийм хүмүүс бол “тааруухан” гэгддэг хүмүүс юм; тэд бол хэрэггүй хог хаягдал мөн. Тийм хүмүүсийг яаж бүтээгдсэн зүйл гэж зохих ёсоор нэрлэж болох юм бэ? Тэд гаднаа гяланцаг, дотроо паланцаг завхарсан оршихуй биш гэж үү? Хүн өөрийгөө Бурхан гэж нэрлэсэн ч бурханлаг чанарын оршихуйг илэрхийлж чадахгүй, Бурханы Өөрийн ажлыг хийж чадахгүй, эсвэл Бурханыг төлөөлж чадахгүй бол Бурхан биш гэдэг нь эргэлзээгүй, учир нь түүнд Бурханы гол чанар байхгүй, Бурханы төрөлхөөсөө биелүүлж чаддаг зүйл түүний дотор оршин байдаггүй. Хэрвээ хүн төрөлхөөсөө хүрч чадахуйц зүйлээ алдвал түүнийг цаашид хүн гэж үзэж болохгүй ба тэрээр бүтээгдсэн зүйлийн байр сууринд зогсох юм уу Бурханы өмнө очиж, Түүнд үйлчлэх үнэ цэнгүй. Түүнчлэн, тэрээр Бурханы нигүүлслийг хүртэх, эсвэл Бурханаар халамжлуулж, хамгаалуулж, төгс болгуулах үнэ цэнгүй. Бурханы итгэлийг алдсан олон хүн Бурханы нигүүлслийг алдсаар байдаг. Тэд өөрсдийн буруу үйлийг үзэн яддаггүйгээр үл барам, Бурханы зам бол буруу гэсэн үзэл санааг ичгүүр сонжуургүйгээр түгээдэг ба тэрслүү хүмүүс бүр Бурханы оршин тогтнолыг ч үгүйсгэдэг. Тийм тэрслүү байдалтай ийм хүмүүс яаж Бурханы нигүүлслийг эдлэх эрхтэй байж чадах юм бэ? Өөрсдийн үүргийг биелүүлдэггүй хүмүүс Бурханы эсрэг маш их тэрсэлдэг ба Түүнд их өртэй, гэсэн ч тэд эргээд Бурханы буруу хэмээн зад шүүмжилдэг. Тийм төрлийн хүмүүс яаж төгс болгуулахад тохирох юм бэ? Энэ нь таягдан хаягдаж, шийтгүүлэхийн дохио биш гэж үү? Бурханы өмнө үүргээ биелүүлдэггүй хүмүүс аль хэдийн хамгийн жигшүүрт гэмт хэрэг үйлдсэн, үүнд үхэх шийтгэл ч хангалтгүй атал тэд Бурхантай маргах ичгүүр сонжуургүй зантай байж, Түүнтэй өрсөлддөг. Тийм хүмүүсийг төгс болгох нь ямар хэрэгтэй юм бэ? Хүмүүс үүргээ биелүүлж чадахгүй бол гэм буруутай, өртэйгөө мэдрэх ёстой; тэд сул дорой, нэмэргүй байдлаа, тэрслүү байдал, завхралаа үзэн ядах ёстой, түүнчлэн өөрсдийн амийг Бурханд өгөх учиртай. Зөвхөн тэр үед л тэд Бурханыг үнэхээр хайрладаг бүтээгдсэн зүйл мөн бөгөөд ийм хүмүүс л Бурханы ерөөл, амлалтыг эдэлж, Түүгээр төгс болгуулахад тохирдог. Тэгвэл та нарын ихэнх нь ямар вэ? Та нарын дунд амьдардаг Бурханд та нар хэрхэн ханддаг вэ? Түүний өмнө үүргээ хэрхэн биелүүлсэн бэ? Та нар амиа золиослоод ч хамаагүй, хийх ёстой бүхнээ чадлынхаа хэрээр хийсэн үү? Та нар юу золиосолсон бэ? Та нар Надаас ихийг хүлээн аваагүй гэж үү? Та нар ялган таньж чадах уу? Надад хэр үнэнч вэ? Надад хэрхэн үйлчилсэн бэ? Би та нарт юу өгч, та нарын төлөө юу хийсэн бэ? Та нар энэ бүхнийг хэмжиж үзсэн үү? Та нар бүгдээрээ өөрсдийн доторх өчүүхэн мөс чанарааараа үүнийг хэмжиж, харьцуулж үзсэн үү? Та нарын үг, үйлдэл хэнд зохистой вэ? Та нарын тийм өчүүхэн золиослол Миний өгсөн бүхнийг хүртэхэд зохистой гэж үү? Надад өөр ямар ч сонголт байгаагүй ба Би та нарт үнэн сэтгэлээсээ хандсан ч та нар Миний талаар

хорон муу сэжиг өвөрлөж, Надад хоёрдмол сэтгэлээр ханддаг. Тэр нь та нарын үүрэг, та нарын цорын ганц чиг үүрэг юм. Тийм биш гэж үү? Та нар бүтээгдсэн зүйлийн үүргээ огтхон ч биелүүлээгүй гэдгээ мэдэхгүй гэж үү? Та нарыг яаж бүтээгдсэн зүйл гэж үзэж болох юм бэ? Илэрхийлж, амьдран харуулж байгаа зүйл чинь юу болохыг та нар тодорхой мэддэггүй гэж үү? Та нар үүргээ биелүүлж чадаагүй боловч Бурханы хүлээцтэй байдал, элбэг дэлбэг нигүүлслийг олж авахаар чармайдаг. Тийм нигүүлсэл нь та нар шиг үнэ цэнгүй, олиггүй хүмүүст зориулан бэлтгэгдээгүй, харин юу ч гуйлгүйгээр, баяртайяа золиосолдог хүмүүст зориулагдсан. Та нар шиг ийм хүмүүс, ийм тааруухан хүмүүс тэнгэрийн нигүүлслийг эдлэхэд огт тохирохгүй. Зовлон зүдүүр болон эцэс төгсгөлгүй шийтгэл л өдөр хоногуудыг чинь дагана! Хэрвээ та нар Надад үнэнч байж чадахгүй бол хувь заяа чинь зовлонгийнх байх болно. Хэрвээ та нар Миний үг болон Миний ажилд хариуцлагатай байж чадахгүй бол төгсгөл чинь шийтгэл байх болно. Бүх нигүүлсэл, ерөөл болон хаанчлалын гайхалтай амьдрал та нартай ямар ч хамаагүй байх болно. Энэ нь та нарын хүртэх ёстой төгсгөл бөгөөд хийсэн зүйлийн чинь үр дагавар юм! Мунхаг, биеэ тоосон хүмүүс чадлынхаа хэрээр хичээдэггүй, үүргээ ч биелүүлдэггүйгээр үл барам, харин ч өөрсдийн хүртэх эрхтэй зүйлийг хүсэж байгаа мэтээр нигүүлсэл гуйн гараа сунгасан. Тэгээд гуйсан зүйлээ авч чадаагүй бол бүр ч итгэлгүй болдог. Тийм хүмүүсийг яаж ухаантай гэж үзэж болох юм бэ? Та нар дорд хэв чанартай, эрүүл ухаангүй, удирдлагын ажлын үеэр хэрэгжүүлэх ёстой үүргээ огт биелүүлэх чадваргүй. Та нарын үнэ цэн аль хэдийн огцом унасан. Та нарт тийм нигүүлсэл үзүүлсний хариуг Надад буцаан төлж чадахгүй байх чинь аль хэдийнээ туйлын тэрслүү үйлдэл бөгөөд та нарыг яллаж, хулчгар зан, чадваргүй байдал, олиггүй зан, үнэ цэнгүй байдлыг чинь харуулахад энэ нь хангалттай. Та нар гараа сунгах ямар эрхтэй юм бэ? Миний ажилд өчүүхэн төдий ч тус болох чадваргүй, үнэнч байх чадваргүй, Миний төлөө гэрчлэлд зогсох чадваргүй байдаг чинь та нарын буруу үйл, алдаа дутагдал атал харин ч та нар Над руу дайрч довтолж, Миний талаар худал ярьж, Намайг зөвт бус гэж гомдоллодог. Энэ нь та нарын үнэнч зан уу? Та нарын хайр уу? Та нар үүнээс илүү өөр ямар ажил хийж чадах вэ? Хийгдсэн бүх ажилд та нар ямар хувь нэмэр оруулсан бэ? Та нар хэр ихийг зарлагадсан бэ? Би та нарыг буруутгаагүйгээрээ аль хэдийн асар их хүлээцтэй байдал харуулсан хэр нь та нар одоо ч Надад ичгүүргүйгээр шалтаг тоочиж, нууцаар Миний тухай гомдоллодог. Та нарт хүн чанарын өчүүхэн ч гэсэн ул мөр байгаа юу? Хэдийгээр хүний үүрэгт хүний оюун санаа болон үзэл холилддог ч чи үүргээ биелүүлж, үнэнч зангаа харуулах ёстой. Хүний ажил дахь хольц нь түүний хэв чанарын асуудал, харин хүн үүргээ биелүүлдэггүй бол энэ нь түүний тэрслүү занг харуулдаг. Хүний үүрэг болон түүний ерөөгдөх, хараагдах эсэхийн хооронд ямар ч хамаарал байхгүй. Үүрэг бол хүний биелүүлэх учиртай зүйл; энэ нь тэнгэрээс өгсөн ажил бөгөөд нөхөн төлбөр, нөхцөл болзол, учир шалтгаанаас хамаарах ёсгүй. Тэгвэл л өөрийн үүргийг биелүүлж байгаа хэрэг юм. Ерөөгдөх гэдэг

нь хүн шүүлт туулсныхаа дараа төгс болгуулж, Бурханы ерөөлийг эдлэх явдал билээ. Хараагдах гэдэг нь шүүлт, гэсгээлт туулсны дараа хүний зан чанар өөрчлөгдөхгүй байх явдал бөгөөд тэд төгс болгуулдаггүй, харин шийтгүүлдэг. Гэвч ерөөгдсөн үү, эсвэл хараагдсан уу гэдгээс үл хамааран, бүтээгдсэн зүйлс өөрсдийн үүргийг биелүүлж, хийх учиртай зүйлээ хийж, чаддаг зүйлээ хийх ёстой; энэ бол хүний, Бурханыг эрэлхийлдэг хүний хийх ёстой наад захын зүйл юм. Чи зөвхөн ерөөгдөхийн тулд үүргээ биелүүлэх ёсгүй ба хараагдахаас айсандаа үүргээ биелүүлэхээс татгалзах ёсгүй. Би та нарт энэ нэг зүйлийг хэлье: Үүргээ биелүүлэх нь хүний хийх учиртай зүйл бөгөөд хэрвээ хүн үүргээ биелүүлж чадахгүй бол энэ нь түүний тэрслүү зан юм. Үүргээ биелүүлэх үйл явцаар л дамжуулан хүн аажмаар өөрчлөгддөг ба энэхүү үйл явцаар үнэнч байдлаа харуулдаг. Тийм болохоор, чи үүргээ биелүүлж чаддаг байх тусмаа, төдий чинээ их үнэнийг хүлээн авч, илэрхийлэл чинь төдий чинээ бодитой болно. Өөрсдийн үүргийг биелүүлэхдээ зүгээр л оромдож, үнэнийг эрж хайдаггүй хүмүүс эцэстээ таягдан хаягдана, учир нь тийм хүмүүс үнэнийг хэрэгжүүлэхдээ үүргээ биелүүлдэггүй ба үүргээ биелүүлэхдээ үнэнийг хэрэгжүүлдэггүй. Тэд бол өөрчлөгдөлгүй улддэг хүмүүс бөгөөд хараагдах болно. Тэдний илэрхийлэл хольцтой байдгаар үл барам, илэрхийлдэг бүхэн нь хорон муу байдаг.

Нигүүлслийн эрин үед Есүс ч бас маш олон үг хэлж, ихээхэн ажил хийсэн. Тэр Исаиагаас ямар ялгаатай байсан бэ? Даниелээс ямар ялгаатай байсан бэ? Тэр чухамдаа эш үзүүлэгч байсан уу? Яагаад Түүнийг Христ гэдэг вэ? Тэдний хоорондох ялгаа юу вэ? Тэд бүгдээрээ үг хэлдэг хүмүүс байсан бөгөөд тэдний үг хүмүүст бараг адилхан харагддаг байсан юм. Тэд бүгд үг хэлж, ажил хийсэн. Хуучин Гэрээний эш үзүүлэгчид зөгнөл хэлдэг байсны адилаар Есүс ч бас тэгсэн. Яагаад тэр вэ? Энд байгаа ялгаа нь ажлын шинж чанарт үндэслэдэг. Энэ асуудлыг ялган танихын тулд чи махан биеийн шинж чанарыг авч үзэх ёсгүй, мөн тэдний үгийн гүн гүнзгий, өнгөц байдлыг ч авч үзэх ёсгүй. Чи үргэлж тэдний ажил болон тэдний ажлын хүнд үзүүлдэг үр нөлөөг эхлээд авч үзэх ёстой. Тухайн үед эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлүүд нь хүний амийг хангаагүй бөгөөд Исаиа, Даниел зэрэг хүмүүсийн хүлээн авсан онгод нь амийн зам биш, ердөө л зөгнөл байсан. Еховагийн шууд илчлэл байгаагүй бол эгэл хүмүүсийн хийх боломжгүй тэр ажлыг хэн ч хийж чадахгүй байх байсан. Есүс ч гэсэн олон үг хэлсэн, гэхдээ тийм үг нь амийн зам байсан ба хүн үүнээс хэрэгжүүлэх замыг олж чадсан юм. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, Есүс бол амь учраас хүний амийг хангаж чадсан; хоёрдугаарт, Тэр хүний гажуудлыг өөрчилж чадсан; гуравдугаарт, Тэрээр эрин үеийг үргэлжлүүлэхийн тулд Еховагийн ажлыг залгамжилж чадсан; дөрөвдүгээрт, Тэр хүний доторх хэрэгцээг ухаарч, хүнд юу дутагдаж байгааг ойлгож чадсан; тавдугаарт, Тэр шинэ эрин үеийг эхлүүлж, хуучин эринийг төгсгөж чадсан. Тийм учраас Түүнийг Бурхан, Христ гэж нэрлэдэг; Тэр Исаиагаас төдийгүй бусад бүх эш үзүүлэгчээс өөр юм. Эш үзүүлэгчдийн ажилтай харьцуулахын тулд Исаиаг авч үзье. Нэгдүгээрт, тэр хүний амийг хангаж

чадаагүй; хоёрдугаарт, шинэ эрин үеийг эхлүүлж чадаагүй. Тэрээр Еховагийн удирдлага дор ажиллаж байсан болохоос шинэ эрин үеийг эхлүүлэх гэж ажиллаагүй. Гуравдугаарт, түүний хэлсэн зүйл өөрөөс нь давсан байв. Тэрээр Бурханы Сүнснээс шууд илчлэл хүлээн авч байсан ба бусад нь тэдгээрийг сонсчихоод ч ойлгохгүй байсан юм. Түүний үг бол ердөө л зөгнөлөөс цаашгүй, Еховагийн оронд хийсэн ажлын нэг талаас хэтрэхгүй байсан гэдгийг батлахад энэ цөөн хэдэн зүйл дангаараа хангалттай билээ. Гэхдээ тэр Еховаг бүрэн төлөөлж чадаагүй. Тэр бол Еховагийн зарц, Еховагийн ажлын хэрэгсэл байсан юм. Тэрээр зөвхөн Хуулийн эрин үе дотор, Еховагийн ажлын цар хүрээн дэх ажлыг л хийж байсан; тэр Хуулийн эрин үеэс цааш ажиллаагүй. Харин Есүсийн ажил өөр байв. Есүс Еховагийн ажлын цар хүрээг давсан; Тэрээр бие махбодтой болсон Бурхан болж ажилласан бөгөөд бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд цовдлогдсон. Өөрөөр хэлбэл, Тэр Еховагийн хийсэн ажлын гаднах шинэ ажлыг гүйцэтгэсэн юм. Энэ нь шинэ эрин үеийг эхлүүлэх явдал байв. Дээр нь нэмээд Тэр хүний хүрч чадахгүй зүйлсийн талаар хэлж чаддаг байлаа. Түүний ажил нь Бурханы удирдлага доторх ажил байсан бөгөөд бүх хүн төрөлхтөнтэй холбоотой байв. Тэр цөөн хэдхэн хүн дээр ажиллаагүй, Түүний ажил цөөн тооны хүмүүсийг удирдахын төлөө ч байгаагүй. Бурхан яаж бие махбодтой хүн болсон, тухайн үед Сүнс яаж илчлэл өгсөн, Сүнс ажлаа хийхийн тулд хэрхэн хүн дээр бууж ирсэн гэх мэтийн тухайд бол эдгээр нь хүний харж, эсвэл хүрч чадахгүй зүйлс юм. Эдгээр баримт нь Тэр бол бие махбодтой болсон Бурхан мөн гэдгийн нотолгоо болох ямар ч боломжгүй. Иймээс, хүнд мэдэгдэхүйц байдаг Бурханы үг ба ажилд л үндэслэн ялгааг нь харж болно. Зөвхөн энэ л бодитой. Яагаад гэвэл, Сүнсний хэрэг явдал чамд харагддаггүй ба Бурхан Өөрөө л тодорхой мэддэг, Бурханы махбод болсон бие ч бүгдийг нь мэдэхгүй; чи Түүний хийсэн ажлаас нь л Бурхан мөн эсэхийг нь баталж чадна. Түүний ажлаас, нэгдүгээрт, Тэр шинэ эрин үеийг нээж чаддаг; хоёрдугаарт, Тэр хүний амийг хангаж, хүний дагах замыг харуулж чаддаг гэдгийг харж болно. Тэр бол Бурхан Өөрөө гэдгийг тогтооход энэ хангалттай. Хамгийн наад зах нь, Түүний хийдэг ажил Бурханы Сүнсийг бүрэн төлөөлж чадах ба Бурханы Сүнс Түүн дотор байгаа гэдгийг ийм ажлаас харж болно. Бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил нь үндсэндээ шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажлыг удирдан чиглүүлж, шинэ ертөнцийг нээхийн төлөө байдаг учраас Тэр бол Бурхан Өөрөө гэдгийг батлахад эдгээр нь дангаараа хангалттай. Тиймээс энэ нь Түүнийг, Исаиа, Даниел болон бусад агуу эш үзүүлэгчдээс ялгаж байгаа юм. Исаиа, Даниел болон бусад нь бүгд өндөр боловсролтой, соёлтой хүмүүс байсан; тэд Еховагийн удирдлага доорх гайхамшигтай хүмүүс байлаа. Бие махбодтой болсон Бурханы махбод ч бас мэдлэг ухаантай, эрүүл ухаанаар дутмаг биш байсан боловч хүн чанар нь нэн хэвийн байв. Тэр эгэл хүн байсан ба хүний энгийн нүд Түүний ямар нэг онцгой хүн чанарыг ялган таньж, эсвэл бусдынхаас ялгаатай хүн чанарыг олж харж чадаагүй юм. Тэр огтхон ч ер бусын юм уу өвөрмөц байгаагүй ба илүү өндөр боловсрол, мэдлэг, онолыг

эзэмшиж байгаагүй. Түүний ярьж байсан амь болоод хөтөлсөн зам нь онолоор дамжуулж, мэдлэгээр дамжуулж, амьдралын туршлагаар дамжуулж, эсвэл гэр бүлийн хүмүүжлээр дамжуулж олдоогүй. Харин ч тэдгээр нь Сүнсний шууд ажил буюу Бурханы махбод болсон биеийн ажил байлаа. Хүн Бурханы талаар асар их үзэлтэй байдаг ба эдгээр үзэл нь ялангуяа хэтэрхий олон бүдэг бадаг, ер бусын элементээс бүрддэг учраас хүний нүдээр бол тэмдэг, гайхамшиг үзүүлж чаддаггүй, хүний сул талуудтай хэвийн Бурхан нь мэдээж Бурхан биш байлаа. Эдгээр нь хүний эндүү ташаа үзэл биш гэж үү? Хэрвээ Бурханы махбод болсон бие хэвийн хүн байгаагүй бол Түүнийг яаж махбод болсон гэж хэлж болох юм бэ? Махбодтой байна гэдэг нь ердийн, хэвийн хүн байх явдал юм; хэрвээ Тэр ер бусын оршихуй байсан бол бие махбодтой биш байх байв. Махбодтой гэдгээ батлахын тулд бие махбодтой болсон Бурхан нь хэвийн махбодыг эзэмших хэрэгтэй байлаа. Энэ нь зүгээр л бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцэлдүүлэхийн төлөө байсан юм. Гэвч, эш үзүүлэгчид болон хүний хөвгүүдийн хувьд ийм байгаагүй. Тэд бол Ариун Сүнсний ашиглаж байсан, авьяас чадвартай хүмүүс байсан; хүний нүдээр бол тэдний хүн чанар нэн агуу байсан ба тэд хэвийн хүн чанараас давсан олон үйл үйлдсэн юм. Энэ шалтгааны улмаас, хүн тэднийг Бурхан мэт үзсэн. Одоо та нар бүгдээрээ үүнийг тодорхой ойлгох ёстой, учир нь энэ бол өнгөрсөн эрин үеийн хүмүүсийн хамгийн амархан төөрч будилдаг асуудал байсаар ирсэн юм. Нэмж хэлэхэд, бие махбодтой болох нь бүх зүйлээс хамгийн нууцлаг нь бөгөөд бие махбодтой болсон Бурханыг хүлээн авах нь хүний хувьд хамгийн хэцүү байдаг. Миний хэлдэг зүйл, чиг үүргээ биелүүлэхэд чинь, мөн бие махбодтой болохын нууцыг ойлгоход чинь тус дэм болдог. Энэ нь бүгд Бурханы удирдлага болон үзэгдэлтэй холбоотой. Та нар үүнийг ойлговол үзэгдлийн талаар буюу Бурханы удирдлагын ажлын талаар илүү их мэдлэг олж авахад илүү тустай байх болно. Ийм маягаар, та нар бас өөр өөр хүмүүсийн биелүүлэх ёстой үүргийн талаар илүү их ойлголт олж авна. Хэдий эдгээр үг та нарт замыг шууд харуулдаггүй ч оролтод чинь асар их тус болдог, учир нь та нарын одоогийн амьдралд үзэгдэл ихээхэн дутагдаж байгаа бөгөөд энэ нь та нарын оролтод ихээхэн садаа тээг болно. Хэрвээ та нар эдгээр асуудлыг ойлгож чадаагүй бол та нарт орох урам зориг байхгүй байх болно. Тэгвэл ийм эрэл хайгуулаар та нар үүргээ яаж чадлынхаа хэрээр биелүүлж чадах юм бэ?

БУРХАН БОЛ БҮХ БҮТЭЭЛИЙН ЭЗЭН

Өмнөх хоёр эрин үеийн ажлын нэг үе шат нь Израильд, нөгөө нь Иудейд явагдсан. Ерөнхийдөө, энэ хоёр үе шатны ажлын аль нь ч Израилийг орхиогүй, тус бүр нь анхны сонгогдсон хүмүүс дээр явагдсан. Тиймээс Ехова Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэж израильчууд итгэдэг. Есүс Иудейд ажиллаж, Өөрийн

цовдлолын ажлыг хэрэгжүүлсэн учраас иудейчүүд Түүнийг Иудейн хүмүүсийн золин Аврагч гэж үздэг. Тэрээр өөр бусад ард түмний биш, гагцхүү иудейчүүдийн хаан юм; Тэр англичуудыг золин авардаг Эзэн биш, бас америкчуудыг золин авардаг Эзэн ч биш, харин израильчуудыг золин авардаг Эзэн; Тэрээр Израильд иудейчүүдийг золин аварсан гэж тэд боддог. Үнэндээ, Бурхан бол бүх зүйлийн Эзэн билээ. Тэр бол бүх бүтээлийн Бурхан юм. Тэр зөвхөн израильчуудын, бас зөвхөн иудейчүүдийн ч Бурхан биш; Тэр бол бүх бүтээлийн Бурхан. Түүний ажлын өмнөх хоёр үе шат Израильд явагдсан нь хүмүүст тодорхой үзлийг бий болгожээ. Ехова Өөрийн ажлыг Израильд хийсэн, Есүс Өөрөө ажлаа Иудейд хэрэгжүүлсэн, түүнчлэн Тэр ажиллахын тулд махбод болсон—ямар ч байсан энэ ажил Израилиас цааш дэлгэрээгүй гэж тэд боддог. Бурхан египетчүүд эсвэл энэтхэгчүүдийн дунд ажиллаагүй; Тэр израильчуудын дунд л ажиллаж байсан. Тиймээс хүмүүс янз бүрийн үзэл бий болгож, Бурханы ажлыг тодорхой цар хүрээгээр хязгаарладаг. Тэд, Бурхан ажиллахдаа, сонгогдсон хүмүүсийн дунд, Израильд ажиллах ёстой; Бурхан израильчуудаас өөр хэн дээр ч ажилладаггүй, Түүний ажилд үүнээс илүү том цар хүрээ гэж үгүй гэдэг. Тэд бие махбодтой болсон Бурханыг дэгтэй байлгах тухайд нэн хатуу чанд байж, Израилийн хил хязгаараас цааш явахыг Түүнд зөвшөөрдөггүй. Энэ бүгд ердөө л хүний үзэл бус уу? Бурхан тэнгэр, газар, бүх зүйлийг бүгдийг бүтээж, бүх бүтээлийг бүтээсэн учраас Тэр Өөрийн ажлыг зөвхөн Израилиар хязгаарлаж яахан болох билээ? Тийм байсан бол Тэр бүх бүтээлийг бүтээхийн хэрэг юу байх билээ? Тэр дэлхийг бүхэлд нь бүтээсэн, Тэр Өөрийн зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөг зөвхөн Израильд ч биш, харин орчлон ертөнц дээрх хүн бүрд хэрэгжүүлсэн. Хятад, Америкийн Нэгдсэн Улс, Нэгдсэн Вант Улс, эсвэл Орост амьдардгаас үл хамааран хүн бүр Адамын үр удам; тэднийг бүгдийг нь Бурхан бүтээсэн. Тэднээс нэг нь ч Бурханы бүтээлийн хил хязгаараас зугтаж, нэг нь ч “Адамын үр удам” хэмээх хаяг шошгоос ангижирч чадахгүй. Тэд бүгд Бурханы бүтээгдсэн зүйл, бүгд Адамын үр сад, мөн бүгд Адам, Ева хоёрын ялзарсан үр удам юм. Бурханы бүтээл бол зөвхөн израильчууд ч биш, харин бүх хүн; ердөө л зарим нь хараагдаж, зарим нь ерөөгдсөн билээ. Израильчуудын тухайд олон хүлээн зөвшөөрмөөр зүйл байдаг; тэд хамгийн бага ялзарсан байсан учраас Бурхан эхэндээ тэдэн дээр ажиллаж байв. Хятадуудыг тэдэнтэй харьцуулшгүй; хавьгүй илүү дорд муу. Тиймээс Бурхан анхандаа Израилийн ард түмний дунд ажилласан бөгөөд Түүний ажлын хоёр дахь үе шат нь зөвхөн Иудейд хэрэгжсэн юм. Энэ нь хүний дунд олон үзэл, дүрэм журам гарахад хүргэсэн. Үнэндээ, хэрвээ хүний үзлийн дагуу үйлдсэн бол Бурхан зөвхөн израильчуудын л Бурхан байх байсан, ийм учраас Тэр Өөрийн ажлыг Харь үндэстнүүдэд дэлгэрүүлж чадахгүй байх байсан, учир нь Тэр бүх бүтээлийн Бурхан биш, зөвхөн израильчуудын Бурхан байх байсан юм. Еховагийн нэр Харь үндэстнүүдийн дунд алдаршиж, Харь үндэстнүүдэд түгэх болно гэж зөгнөлд хэлсэн. Яагаад ингэж зөгнөсөн бэ? Хэрвээ Бурхан зөвхөн израильчуудын Бурхан байсан бол Тэр Израильд л ажиллах байв. Цаашлаад, Тэр

энэ ажлыг түгээхгүй, ийм зөгнөлийг айлдахгүй байх байлаа. Тэр энэ зөгнөлийг айлдсан учраас Харь үндэстнүүдийн дунд болоод бүх улс үндэстэн, газар нутагт Өөрийн ажлыг гарцаагүй дэлгэрүүлнэ. Нэгэнт Тэр үүнийг хэлсэн учраас Тэр үүнийг хийх ёстой; энэ бол Түүний төлөвлөгөө, учир нь Тэр тэнгэр, газар болоод бүх зүйлийг бүтээсэн Эзэн, бүх бүтээлийн Бурхан билээ. Тэр израильчуудын дунд, эсвэл бүх Иудей даяар ажиллаж байна уу гэдгээс үл хамааран Түүний хийдэг ажил нь бүх орчлон ертөнцийн, бүх хүн төрөлхтний ажил юм. Агуу улаан лууны улс орон—Харь үндэстэнд Түүний өнөөдрийн хийж буй ажил нь бас л бүх хүн төрөлхтний ажил билээ. Израиль нь газар дээрх Түүний ажлын суурь байж болно; үүний адилаар Хятад улс ч гэсэн Харь үндэстнүүдийн дундах Түүний ажлын суурь болж болно. “Еховагийн нэр Харь үндэстнүүдийн дунд алдарших болно” гэсэн зөгнөлийг Тэр одоо биелүүлсэн бус уу? Харь үндэстнүүдийн дундах Түүний ажлын эхний алхам нь агуу улаан лууны улс оронд хийж байгаа Түүний энэ ажил юм. Тэрхүү бие махбодтой болсон Бурхан энэ газар нутагт ажиллаж, энэ хараагдсан хүмүүсийн дунд ажиллах ёстой нь ялангуяа хүний үзэлтэй нийцдэггүй; энэ хүмүүс бол хамгийн дорд, ямар ч үнэ цэнгүйн дээр тэд анх Еховад хаягдсан билээ. Хүмүүс бусад хүнд хаягдаж болно, харин тэд Бурханд хаягдсан бол хамгийн дорд байр суурьтай, хамгийн дорд үнэ цэнтэй байдаг. Бурханы бүтээгдсэн зүйлийн хувьд, Сатанд эзэмдүүлж, бусад хүнд хаягдах нь маш зовлонтой санагддаг зүйл боловч, бүтээгдсэн зүйл Бүтээгчдээ хаягдана гэдэг нь тэд үүнээс дорд байр суурьтай болох боломжгүй гэсэн үг юм. Моабын үр удам хараагдаж, энэхүү харанхуй бүдүүлэг улсад төрсөн; Харанхуйн нөлөөнд байдаг бүх хүнээс Моабын үр удам л эргэлзээгүй хамгийн дорд байр суурьтай. Энэ хүмүүс эдүгээ хүртэл хамгийн дорд байр суурьтай байсан учраас тэдэнд хийгдсэн ажил хүний үзлийг эвдэж хамгийн сайн чаддаг бөгөөд мөн Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөнд бүхэлд нь хамгийн үр ашигтай юм. Энэ хүмүүсийн дунд ийм ажил хийх нь хүний үзлийг эвдэх хамгийн сайн арга зам бөгөөд үүгээрээ Бурхан эрин үеийг эхлүүлдэг; үүгээр Тэр хүний бүх үзлийг эвддэг; үүгээр Тэр Нигүүлслийн эрин үе даяарх ажлыг төгсгөдөг. Түүний анхны ажил Израилийн хил хязгаар дотор Иудейд хэрэгжсэн; Тэр эрин үеийг эхлүүлэх ямар ч ажлыг Харь үндэстнүүдийн дунд хийгээгүй. Ажлын эцсийн үе шат нь зөвхөн Харь үндэстнүүдийн дунд хэрэгжээд зогсохгүй, хараагдсан хүмүүсийн дунд илүү их хэрэгждэг. Энэ нэг зүйл бол Сатаныг хамгийн их гутаан доромжлох боломжтой нотолгоо учраас Бурхан, орчлон ертөнц дээрх бүх бүтээлийн Бурхан, бүх зүйлийн Эзэн, амьтай бүхний хувьд шүтэн мөргөх объект нь “болдог”.

Бурхан ямар шинэ ажил эхлүүлснийг одоо ч ойлгоогүй хүмүүс өнөөдөр бий. Харь үндэстнүүдийн дунд Бурхан шинэ эхлэлийн үүдийг нээсэн. Тэр шинэ эрин үеийг эхлүүлж, шинэ ажлыг санаачилсан, Тэр энэ ажлыг Моабын үр удам дээр гүйцэтгэдэг. Энэ Түүний хамгийн шинэ ажил бус уу? Түүхэнд хэн ч энэ ажлыг өмнө нь туулж байгаагүй. Үүнийг ойлгох нь байтугай хэн ч энэ талаар сонсож байгаагүй.

Бурханы мэргэн ухаан, Бурханы гайхамшиг, Бурханы ойлгогдошгүй байдал, Бурханы агуу байдал, Бурханы ариун байдал бүгд ажлын энэ үе шат буюу эцсийн өдрүүдийн ажлаар дамжин илрэхэд хүрдэг. Хүний үзлийг эвдэх шинэ ажил энэ бус уу? “Бурхан Моабыг харааж, Моабын үр удмыг хаях болно гэж хэлсэн байхад одоо яаж тэднийг аварч болох юм бэ?” хэмээн боддог хүмүүс бий. Эдгээр нь Бурханы хараасан, Израилиас хөөгдөн гарсан Харь үндэстнүүд юм; израильчууд тэднийг “Харийн ноход” гэж нэрлэж байсан. Хүн бүрийн үзэл бодлоор бол, тэд зөвхөн Харийн ноход байгаад зогсохгүй, бүр долоон дор, сүйрлийн хөвгүүд юм; өөрөөр хэлбэл, тэд Бурханы сонгосон хүмүүс биш. Тэд Израилийн газар нутаг дотор төрсөн боловч Израилийн ард түмэнд харьяалагддаггүй бөгөөд Харь үндэстнүүд рүү хөөгдсөн. Тэд бол хамгийн дорд хүмүүс юм. Тэд хүн төрөлхтний дундаас хамгийн дорд нь учраас л Бурхан шинэ эрин үеийг эхлүүлэх ажлаа тэдний дунд хэрэгжүүлдэг, учир нь тэд ялзарсан хүн төрөлхтний төлөөлөгч билээ. Бурханы ажил сонголттой агаад зорилготой; өнөөдөр энэ хүмүүст хийж буй Түүний ажил нь мөн бүтээл дээр гүйцэтгэдэг ажил юм. Ноа Бурханы бүтээсэн зүйл байсан, түүний үр удам ч мөн адил. Дэлхий дээрх мах, цуснаас бүтсэн хэн боловч Бурханы бүтээсэн зүйл билээ. Бурханы ажил бүх бүтээлд чиглэдэг; бүтээгдсэнийхээ дараа хараагдсан эсэхээс энэ нь хамаардаггүй. Түүний удирдлагын ажил нь хараагдаагүй, сонгогдсон хүмүүст зөвхөн биш, бүх бүтээлд чиглэдэг. Бурхан Өөрийн ажлыг бүтээлийнхээ дунд хэрэгжүүлэхийг хүсдэг тул Тэр үүнийг амжилттай хэрэгжүүлж дуусгах нь гарцаагүй, Тэрээр Өөрийнх нь ажилд ашиг тустай хүмүүсийн дунд ажиллана. Тиймээс хүмүүсийн дунд ажиллахдаа Тэрээр бүх тогтсон ёсыг эвддэг; Түүний хувьд “хараагдсан”, “гэсгээгдсэн”, “ерөөгдсөн” гэдэг үг ямар ч утгагүй! Иудей хүмүүс бол сайн, Израилийн сонгогдсон хүмүүс ч бас адил; тэд бол сайн хэв чанар, хүн чанартай хүмүүс мөн. Ехова эхэндээ Өөрийн ажлыг тэдний дунд эхлүүлж, Өөрийн хамгийн анхны ажлыг гүйцэтгэсэн, гэхдээ өнөөдөр тэдэн дээр байлдан дагуулах ажлыг гүйцэтгэх нь утгагүй байх байлаа. Хэдийгээр тэд бас бүтээлийн нэг хэсэг, тэдэнд олон эерэг зүйл байж болох ч ажлын энэ үе шатыг тэдний дунд гүйцэтгээд утгагүй байх болно; Бурхан хүмүүсийг байлдан дагуулж чадахгүй, бас бүх бүтээлийг үнэмшүүлж ч чадахгүй байх болно. Ийм л учраас агуу улаан лууны улс орны хүмүүст Өөрийн ажлыг шилжүүлэх хэрэгтэй юм. Үүний хамгийн чухал ач холбогдол нь, Тэрээр эрин үеийг эхлүүлж, бүх дүрэм журам, хүний үзлийг эвдэж, Нигүүлслийн эрин үеийн ажлыг бүхэлд нь дуусгах билээ. Хэрвээ Түүний одоогийн ажил израильчуудын дунд явагдсан бол, Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө эцэс болох үед Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан, израильчууд л Бурханы сонгосон хүмүүс, израильчууд л Бурханы ерөөл, амлалтыг өвлөх эрхтэй гэж хүн бүхэн бодох байв. Эцсийн өдрүүдэд агуу улаан лууны улсын Харь үндэстэнд бие махбодтой болсон Бурхан, Бурхан бол бүх бүтээлийн Бурхан хэмээх ажлыг гүйцэлдүүлдэг; Тэрээр Өөрийн удирдлагын ажлыг бүхэлд нь гүйцээж, агуу улаан лууны улс оронд Өөрийн ажлын

гол хэсгийг дуусгадаг. Ажлын энэ гурван үе шатны гол цөм нь хүнийг аврах—тухайлбал, бүх бүтээл Бүтээгчид шүтэн мөргөдөг болгох юм. Тиймээс ажлын үе шат бүр асар их утга учиртай; Бурхан утга учиргүй, үнэ цэнгүй юу ч хийхгүй. Нэг талаар, ажлын энэ үе шат нь шинэ эрин үеийн үүдийг нээж, өмнөх хоёр эрин үеийг төгсгөдөг; нөгөө талаар энэ нь, хүний бүх үзэл болоод хүний итгэл, мэдлэгийн бүх хуучин арга замыг эвддэг. Өмнөх хоёр эрин үеийн ажил хүний өөр үзлийн дагуу явагдсан; энэ үе шат нь харин хүний үзлийг бүрэн таягдан хаяж, ингэснээрээ хүн төрөлхтнийг бүрэн байлдан дагуулна. Моабын үр удмыг байлдан дагуулснаар, Моабын үр удмын дунд явагдсан ажлаар дамжуулан Бурхан орчлон ертөнц даяарх бүх хүнийг байлдан дагуулна. Түүний ажлын энэхүү үе шатны гүн гүнзгий ач холбогдол, Түүний ажлын энэ үе шатны хамгийн үнэ цэнтэй тал нь энэ юм. Байр суурь чинь дорд, үнэ цэн чинь доогуур гэдгээ одоо мэдсэн ч гэсэн чи хамгийн баяр хөөртэй зүйлтэй учирсан гэдгээ мэдрэх болно: Чи асар их ерөөл өвлөж, үлэмж их амлалтыг хүлээж авсны дээр Бурханы энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд тусалж чадна. Чи Бурханы жинхэнэ төрхийг харсан, Бурханы төрөлх зан чанарыг мэддэг, Бурханы хүслийг биелүүлдэг. Бурханы ажлын өмнөх хоёр үе шат Израильд явагдсан. Хэрвээ эцсийн өдрүүд дэх Түүний ажлын энэ үе шат мөн л израильчуудын дунд явагдсан бол зөвхөн израильчууд л Бурханы сонгосон хүмүүс юм байна гэж бүх бүтээл бодоод зогсохгүй, Бурханы удирдлагын төлөвлөгөө ч бас бүхэлдээ хүссэн үр дүндээ хүрч чадахгүй. Түүний ажлын хоёр үе шат Израильд явагдаж байх үед, Харь үндэстнүүдийн дунд ямар ч шинэ ажил, бас шинэ эринийг эхлүүлэх ямар ч ажил явагдаагүй. Өнөөдрийн ажлын үе шат—шинэ эринийг эхлүүлэх ажлыг эхлээд Харь үндэстнүүдийн дунд явуулдаг бөгөөд улмаар эхлээд Моабын үр удам дунд хэрэгжүүлж, ингэснээрээ бүхэл бүтэн эрин үеийг эхлүүлдэг. Бурхан хүний үзэл дотор агуулагддаг аливаа мэдлэгийг сүйтгэж, нэгийг ч үлдээхийг зөвшөөрөөгүй. Тэрээр Өөрийн байлдан дагуулах ажилдаа хүний үзлийг, тэдгээр хүний мэдлэгийн хуучин, эртний арга замыг сүйтгэсэн. Бурхан байхад ямар ч дүрэм журам байхгүй, Бурханы юу нь ч хуучин биш, Түүний хийдэг ажил бол бүхэлдээ чөлөөлөгдсөн, бүхэлдээ эрх чөлөөтэй бөгөөд Түүний хийдэг бүхэн зөв гэдгийг Тэр хүмүүст харуулдаг. Бүтээлийн дунд Түүний хийдэг ямар ч ажилд чи бүрэн захирагдах ёстой. Түүний хийдэг бүх ажил утга учиртай бөгөөд хүний сонголт, үзлийн дагуу биш, харин Түүний хүсэл, мэргэн ухааны дагуу хийгддэг. Тэр Өөрийнх нь ажилд ач тустай зүйлсийг л хийдэг; хэрвээ ямар нэг зүйл Түүний ажилд ашиг тусгүй бол хэчнээн сайн байсан ч Тэр үүнийг хийхгүй! Тэр Өөрийн ажлын утга учир, зорилгын дагуу ажлынхаа хүлээн авагч болон байршлыг сонгож ажилладаг. Тэр ажиллаж байхдаа өнгөрсөн үеийн дүрмийг баримталдаггүй, хуучин хэв загварыг ч дагадаггүй. Харин Тэр ажлын ач холбогдлын дагуу Өөрийн ажлыг төлөвлөдөг. Эцэст нь Тэр жинхэнэ үр дүн, хүлээсэн зорилгодоо хүрнэ. Хэрвээ чи эдгээр зүйлийг өнөөдөр ойлгохгүй бол энэхүү ажил чамд ямар ч үр нөлөө үзүүлэхгүй.

АРВАН ГУРВАН ЗАХИДЛЫН ТАЛААР ЧИ ЯМАР ХАНДЛАГА БАРИМТАЛДАГ ВЭ?

Библийн Шинэ Гэрээ Паулын арван гурван захидлыг агуулдаг. Өөрийн ажлыг хийх хугацаандаа Паул Есүс Христэд итгэдэг чуулгануудад хандан энэ арван гурван захиаг бичсэн юм. Өөрөөр хэлбэл, Есүсийг тэнгэр өөд гарсны дараа Паул өргөгдөж, энэ захианууудыг бичжээ. Түүний захианууд нь Эзэн Есүс нас барсныхаа дараа дахин амилж, тэнгэр өөд гарсан тухай гэрчлэл бөгөөд бас гэмших, загалмай үүрэх замыг түгээдэг. Мэдээж, энэ бүх сургаал, гэрчлэл нь тухайн үеийн Иудей хавийн янз бүрийн газарт байсан ах эгч нарт зааж сургах зорилготой байлаа, учир нь тэр үед Паул Эзэн Есүсийн зарц байсан бөгөөд Эзэн Есүст гэрчлэл хийхийн тулд өргөгдсөн байв. Ариун Сүнсний ажлын үе шат болгоны үеэр Түүний өөр өөр ажлыг гүйцэтгэхийн тулд, өөрөөр хэлбэл, Бурханы Өөрөө гүйцэлдүүлдэг ажлыг үргэлжлүүлэхийн тулд элчийн ажлыг хийхээр янз бүрийн хүмүүс өргөгддөг. Хэрвээ Ариун Сүнс шууд хийж, нэг ч хүнийг өргөөгүй бол ажлыг гүйцэтгэхэд тун хэцүү байх байв. Тийм болохоор Паул, Дамаск явах замдаа цохиулж, дараа нь Эзэн Есүсийн гэрчлэгч байхаар өргөгдсөн нэгэн болсон юм. Тэрээр Есүсийн арван хоёр шавиас тусдаа элч байлаа. Сайн мэдээ түгээхээс гадна бас янз бүрийн газарт байсан чуулгануудыг хариулах ажлыг хариуцсан бөгөөд энэ нь чуулганы ах эгч нарыг харж хандах, өөрөөр хэлбэл, Эзэн дотор ах эгч нарыг удирдан хөтлөх явдлыг хамарч байсан юм. Паулын гэрчлэл нь Эзэн Есүс дахин амилж, тэнгэр өөд гарсан тухай баримтыг мэдэгдэх, түүнчлэн гэмших, улайх, загалмайн замаар алхах талаар хүмүүст зааж сургахын төлөө байлаа. Тэрээр тухайн үедээ Есүс Христийг гэрчлэгчдийн нэг байсан юм.

Паулын арван гурван захидлыг Библид ашиглахаар сонгосон. Тэрээр арван гурван захидлыг бүгдийг нь янз бүрийн газарт байсан хүмүүсийн өөр өөр байдалд хандаж бичсэн юм. Ариун Сүнс сэтгэлийг нь хөдөлгөөд тэдгээрийг бичсэн бөгөөд элчийн байр сууринаас (Эзэн Есүсийн зарцын өнцгөөс) газар сайгүй байсан ах эгч нарт зааж сургажээ. Тиймээс Паулын захианууд зөгнөлөөс, эсвэл шууд үзэгдлээс үүсээгүй, харин түүний хариуцсан ажлаас бий болсон юм. Эдгээр захиа нь хачин биш, мөн ухан ойлгоход зөгнөлүүд шиг хэцүү биш. Тэдгээр нь зүгээр л захиа шиг бичигдсэн бөгөөд зөгнөлийг ч, нууцыг ч агуулдаггүй; гагцхүү ердийн сургамжийн үгсийг л агуулдаг. Хэдийгээр олон үгийг нь ухаарахад бэрх, ойлгоход хэцүү байж болох боловч тэдгээр нь зөвхөн Паулын хувийн тайлбар, Ариун Сүнсний гэгээрлээс л урган гарсан юм. Паул ердөө л элч байсан; тэрээр эш үзүүлэгч биш, харин Эзэн Есүсийн ашигладаг зарц байв. Янз бүрийн газар нутгаар явах зуураа чуулгануудын ах эгч нарт захиа бичсэн, эсвэл өвчтэй байх зуураа ялангуяа санаанд нь байсан боловч очиж чадахгүй байсан чуулгануудад хандан бичсэн билээ. Ийнхүү түүний захианууудыг хүмүүс хадгалсан ба дараа нь хожмын үеийнхэн цуглуулж, цэгцлээд

Библид дөрвөн сайн мэдээний дараа оруулжээ. Мэдээж, тэд түүний бичсэн бүх шилдэг захианаас сонгож, эмхэтгэсэн юм. Эдгээр захидал нь чуулганы ах эгч нарын аминд ач тустай байсан бөгөөд тухайн үедээ онцгой их алдартай байлаа. Эдгээрийг бичихдээ Паул, хэрэгжүүлэлтийн замыг олох боломжийг ах эгч нарт олгох сүнслэг зохиол юм уу хувийн туршлагаа илэрхийлэх сүнслэг намтар бичих зорилготой байгаагүй; мөн зохиолч болохын тулд ном бичихээр санаархаагүй. Тэр зүгээр л Эзэн Есүс Христийн чуулганы ах эгч нартаа захиа бичиж байсан юм. Паул өөрийнхөө ачаа, Эзэн Есүсийн хүсэл, ирээдүйн хүмүүст Тэр юу даалгасан тухай хэлэхийн тулд ах, эгч нартаа зарцын байр сууринаас зааж сургасан билээ. Паулын хийсэн ажил энэ байв. Түүний үг ирээдүйн бүх ах эгч нарын туршлагад нэлээд сургамжтай байлаа. Энэ олон захианд түүний ярилцсан үнэн нь Нигүүлслийн эрин үеийн хүмүүсийн хэрэгжүүлэх учиртай зүйл байсан учраас хожмын үеийнхэн энэ захианууудыг Шинэ Гэрээнд оруулжээ. Паулын төгсгөл юу болж дууссан нь хамаагүй, тэр бол тухайн үедээ ашиглагдаж байсан ба чуулгануудын ах эгч нараа дэмжиж байсан хүн билээ. Түүний гол чанар болон анх цохигдож байсан нь түүний төгсгөлийг тодорхойлсон. Тэрээр Ариун Сүнсний ажилтай байсан учраас тухайн үед эдгээр үгийг хэлж чадсан бөгөөд энэхүү ажлаас болж Паул чуулгануудын төлөө ачаа үүрсэн юм. Тийм болохоор ах эгч нараа хангаж чаддаг байв. Гэвч зарим нэг онцгой нөхцөл байдлын улмаас Паул чуулганууд руу биечлэн очиж, ажиллаж чадаагүй тул Эзэн дотор ах эгч нартаа сануулахын тулд захиа бичсэн юм. Анх Паул Эзэн Есүсийн шавь нарыг хяхан хавчиж байсан боловч Есүсийг тэнгэр өөд гарсны дараа буюу “гэрэл харсныхаа” дараа Эзэн Есүсийн шавь нарыг хяхан хавчихаа больж, Эзэний замын төлөө сайн мэдээ тунхаглаж байсан ариун хүмүүсийг ч хавчихаа больжээ. Есүс өөрт нь хурц гэрэл болж харагдсаны дараа Паул, Эзэний даалгаврыг хүлээн авч, улмаар сайн мэдээ түгээхийн тулд Ариун Сүнсний ашигладаг хүн болсон юм.

Тухайн үеийн Паулын ажил нь ердөө ах эгч нараа дэмжиж, хангахын төлөө байв. Тэрээр ажил мэргэжилтэй болж, зохиол бүтээл туурвиж, өөр бусад арга замыг нээж, эсвэл Библиэс ангид зам олоод түүгээрээ чуулганы энэ хүмүүсийг хөтөлж, ингэснээрээ тэднийг бүгдийг нь шинэ оролтод хүргэхийг хүсдэг зарим хүнтэй адил байгаагүй. Паул бол ашиглагдсан хүн байсан; хийсэн зүйлээрээ тэр ердөө л үүргээ биелүүлж байсан юм. Хэрвээ чуулгануудын төлөө ачаа үүрээгүй бол үүргээ хөсөрдүүлсэнд тооцогдох байлаа. Хэрвээ ямар нэгэн сүйтгэж бусниулсан зүйл тохиолдсон бол, эсвэл чуулганд урвалтын хэрэг гарч, тэнд байгаа хүмүүсийг хэвийн бус байдалтай болгосон бол Паулыг ажлаа зохих ёсоор биелүүлээгүй гэж тооцох байв. Ажилчин чуулганы ачааг үүрч, бас чадлынхаа хэрээр ажилладаг бол энэхүү хүн ашиглагдахад тохирсон, чадвартай ажилчин мөн гэдгийг нотолдог. Хэрвээ хүн чуулганы төлөө ямар ч ачаа мэдэрдэггүй, ажилдаа ямар ч үр дүнд хүрдэггүй, өөрийнх нь удирддаг ихэнх хүмүүс сул дорой, эсвэл бүр унаж доройтдог бол тийм ажилчин үүргээ биелүүлээгүй байдаг. Түүнчлэн, Паул ч үүнээс ангид

байгаагүй тул чуулгануудыг харж хандаж, ах эгч нартаа ойр ойрхон захиа бичих ёстой байлаа. Ийм байдлаар тэрээр чуулгануудыг хангаж, ах эгч нарыг харж хандаж чадсан; ийм маягаар л чуулганууд түүнээс хангалт, хариулга хүлээн авч чадсан юм. Түүний бичсэн захианы үгс тун гүн гүнзгий байсан боловч Ариун Сүнсний гэгээрэлд хүрсний үндсэн дээр ах эгч нарт хандан бичигдсэн бөгөөд тэрээр хувийн туршлага, мэдэрсэн ачаагаа бичвэртээ нэгтгэжээ. Паул ердөө л Ариун Сүнсний ашигладаг хүн байсан бөгөөд түүний захианы агуулга нь тэр чигтээ хувийн туршлагатай нь холилдсон байв. Түүний хийсэн ажил Ариун Сүнсний шууд хийсэн ажлыг биш, элчийн ажлыг л төлөөлсөн бөгөөд энэ нь бас Христийн ажлаас ялгаатай байлаа. Паул ердөө үүргээ биелүүлж байсан, тийм учраас тэрээр өөрийн ачаа болон хувийн туршлага, мэдлэг ухаанаар Эзэн дотор ах эгч нараа хангасан юм. Паул хувийн мэдлэг ухаан, ойлголтоор хангаснаараа зүгээр л Бурханы даалгасан ажлыг гүйцэтгэж байсан; энэ нь мэдээж Бурханы Өөрийн шууд гүйцэтгэсэн ажил байгаагүй. Иймээс Паулын ажил хүний туршлага болон чуулганы ажлын талаарх хүний үзэл бодол, ойлголттой холилдсон байлаа. Гэхдээ хүний эдгээр үзэл бодол, ойлголтыг муу ёрын сүнсний ажил юм уу мах, цусны ажил гэж хэлж болохгүй; тэдгээрийг Ариун Сүнсний гэгээрүүлсэн хүний мэдлэг, туршлага гэж л хэлж болно. Үүгээрээ Би Паулын захианууд нь тэнгэрээс ирсэн ном биш гэж хэлж байгаа юм. Тэдгээр нь ариун биш, Ариун Сүнс айлдаж, илэрхийлсэн юм огт биш; ердөө л чуулганы төлөөх Паулын ачааны илэрхийлэл билээ. Энэ бүхнийг хэлж байгаагийн минь зорилго бол Бурханы ажил болон хүний ажлын ялгааг та нарт ойлгуулах явдал: Бурханы ажил Бурханыг Өөрийг нь төлөөлдөг, харин хүний ажил хүний үүрэг, туршлагыг төлөөлдөг. Бурханы хэвийн ажлыг хүний хүсэл, Бурханы ер бусын ажлыг Бурханы ажил гэж үзэх ёсгүй; түүнчлэн хүний сүрлэг номлолыг Бурханы айлдвар, тэнгэрээс ирсэн ном гэж авч үзэх ёсгүй. Ийм бүх үзэл бодол нь ёс зүйгүй юм. Паулын арван гурван захидлыг задлан шинжлэхийг минь сонсоод олон хүн, Паулын захианууудыг унших ёсгүй, Паул бол асар их нүгэлтэй хүн гэж боддог. Миний үг хатуу цэвдэг бөгөөд Паулын захидлын талаарх Миний үнэлгээ буруу, тэр захианууудыг хүний туршлага, ачааны илэрхийлэл гэж үзэж болохгүй гэж боддог хүн бүр ч олон бий. Харин ч тэдгээрийг Бурханы үг гэж үзэх ёстой, тэдгээр нь Иоханы Илчлэлийн ном шиг чухал, тэдгээрийг хасаж, эсвэл дээр нь юм нэмж болохгүй, түүнчлэн хааш яаш тайлбарлаж болохгүй гэж тэд боддог. Хүний энэ бүх мэдэгдэл буруу биш гэж үү? Энэ нь бүхэлдээ, хүмүүст эрүүл ухаан байхгүйгээс болж байгаа бус уу? Паулын захианууд нь хүмүүст ихээхэн ач тустай бөгөөд аль хэдийн 2,000 гаруй жилийн түүхтэй болчихсон. Гэхдээ түүний тухайн үед хэлсэн зүйлийг ухан ойлгож чаддаггүй олон хүн өнөөг хүртэл байсаар байна. Паулын захианууд бол бүх Христийн шашны хамгийн агуу бүтээл бөгөөд хэн ч тэдгээрийг тайлж чадахгүй, хэн ч бүрэн ойлгож чадахгүй гэж хүмүүс үздэг. Үнэн хэрэгтээ эдгээр захиа нь яг л сүнслэг хүний намтартай адил бөгөөд Есүсийн үгтэй юм уу Иоханы харсан агуу үзэгдэлтэй харьцуулж болохгүй. Эсрэгээрээ, Иоханы харсан зүйл нь

тэнгэрээс ирсэн агуу үзэгдэл буюу хүний хүрч үл чадах Бурханы Өөрийнх нь ажлын зөгнөл байсан байхад Паулын захианууд нь хүний харж, туулсан зүйлийн талаарх дүрслэл төдий юм. Тэдгээр нь хүний хийж чадах зүйл болохоос зөгнөл ч биш, үзэгдэл ч биш; зүгээр л янз бүрийн газрууд руу илгээсэн захиа билээ. Гэхдээ тухайн үеийн хүмүүсийн хувьд Паул ажилчин байсан бөгөөд өөрт нь даалгасан зүйлийг хүлээн авсан хүн байсан учраас түүний үг үнэ цэнтэй байв. Ийм учраас түүний захианууд нь Христийг эрж хайсан бүх хүнд ач тустай байсан юм. Хэдийгээр тэр үгсийг Есүс биечлэн хэлээгүй боловч эцсийн эцэст тэдгээр нь тухайн үедээ чухал байжээ. Тийм болохоор Паулын дараах үеийн хүмүүс захианууд ыг нь Библид оруулж, улмаар өнөөг хүртэл уламжлан ирэх боломжтой болгосон юм. Юу хэлээд байгааг минь та нар ойлгож байна уу? Би зүгээр л та нарт эдгээр захианы талаар үнэн зөв тайлбар өгч, хүмүүсийн хувьд лавлагаа болдог ач тус, үнэ цэнийг нь үгүйсгэлгүйгээр задлан шинжилж байна. Миний үгийг уншсаныхаа дараа та нар Паулын захианууд ыг үгүйсгээд зогсохгүй, тэдгээрийг тэрс үзэл, үнэ цэнгүй гэж тодорхойлох юм бол ойлгож ухамсарлах чадвар, мэдлэг ухаан, аливааг үнэлэх үнэлэмж чинь дэндүү ядмаг юм гэж л хэлж болно; Миний үгийг хэтэрхий өрөөсгөл гэж хэлж мэдээж болохгүй. Та нар одоо ойлгож байна уу? Та нарын ойлгох ёстой чухал зүйл бол тухайн үеийн Паулын ажлын бодит нөхцөл байдал болон захианууд аа бичих үеийнх нь цаад учир юм. Хэрвээ та нар эдгээр нөхцөлийн талаар зөв үзэл бодолтой байвал Паулын захидлуудын талаар ч бас зөв үзэл бодолтой байх болно. Үүний зэрэгцээ тэдгээр захидлын мөн чанарыг ухан ойлгомогц Библийн талаарх үнэлгээ чинь зөв болох бөгөөд хожмын үеийн хүмүүс яагаад ийм олон жилийн турш Паулын захидлуудыг ихэд шүтсээр ирснийг, түүнчлэн яагаад бүр ч олон хүн Паулыг Бурхан мэт үзсээр ирснийг чи ойлгоно. Хэрвээ та нар ойлгоогүй байсан бол мөн л тэгж бодох байсан бус уу?

Бурхан Өөрөө биш нэгэн Бурханыг Өөрийг нь төлөөлж чадахгүй. Паулын ажлыг хүний үзэл бодлын нэг хэсэг, Ариун Сүнсний гэгээрлийн нэг хэсэг гэж л хэлж болно. Паул Ариун Сүнсний гэгээрэлтэйгээр, хүний үзэл бодлоор эдгээр үгийг бичсэн юм. Энэ нь ховор зүйл биш. Тиймээс түүний үгэнд хүний зарим туршлага холилдсон байх нь зайлшгүй бөгөөд тухайн үеийн ах, эгч нараа хангаж, дэмжихийн тулд тэрээр хожим нь хувийн туршлагаа ашигласан юм. Түүний бичсэн захианууд ыг амийн судалгаа гэж ангилж болохгүй, мөн намтар юм уу мэдээ гэж ч ангилж болохгүй. Түүнчлэн, эдгээр нь чуулганы хэрэгжүүлж байсан үнэн ч биш, чуулганы захиргааны зарлиг ч биш байлаа. Ачаа үүрсэн нэгэн—Ариун Сүнсний даалгасан ажилтай—хүний хувьд энэ бол зүгээр л хийх ёстой зүйл нь юм. Хэрвээ Ариун Сүнс хүмүүсийг өргөж, ачаа өгсөн боловч тэд чуулганы ажлыг үүрдэггүй, чуулганы хэрэг явдлыг сайн удирдаж чаддаггүй, эсвэл бүх асуудлыг нь хангалттай шийдвэрлэж чаддаггүй бол тэр хүмүүс үүргээ зохих ёсоор биелүүлдэггүй гэдгийг энэ нь нотолдог. Тиймээс ажлынхаа явцад элч захиа бичиж чадна гэдэг тийм ч нууцлаг зүйл биш юм. Энэ нь тэдний ажлын нэг хэсэг байв; тэд үүнийг заавал хийх ёстой

байлаа. Эдгээр захиаг бичих зорилго нь амийн судалгаа, эсвэл сүнслэг намтар бичих явдал биш, ариун хүмүүст зориулан өөр нэгэн гарц нээх явдал мэдээж бүр ч биш байв. Харин ч тэд чиг үүргээ биелүүлэх, Бурханы үнэнч зарц байхын тулд үүнийг хийсэн бөгөөд ийнхүү өөрсдөд нь Бурханы даалгасан ажлыг гүйцэлдүүлснээр Түүнд тайлан өгч чадах байв. Тэд өөрсдийнхөө төлөө болон ах эгч нарынхаа төлөө хариуцлага үүрч, ажлаа сайн хийж, чуулганы ажил хэргийг үнэн сэтгэлээсээ авч үзэх ёстой байлаа: Энэ бүхэн нь ердөө тэдний ажлын нэг хэсэг байсан юм.

Хэрвээ та нар Паулын захианууудын талаар ойлгож авсан бол Петр, Иохан хоёрын захидлуудын талаар ч бас үнэн зөв санаа бодол, үнэлэмжтэй болно. Та нар эдгээр захиаг тэнгэрээс ирсэн ариун, халдашгүй ном гэж дахин хэзээ ч үзэхгүй, Паулыг Бурхан гэж бүр ч бодохгүй. Эцсийн эцэст Бурханы ажил хүний ажлаас өөр, түүнчлэн Түүний илэрхийлэл яаж тэднийхтэй адилхан байж болох юм бэ? Бурханд Өөрийн гэсэн онцгой зан чанар байдаг, харин хүнд биелүүлэх учиртай үүрэг гэж бий. Бурханы зан чанар ажлаар нь илэрхийлэгддэг байхад хүний үүрэг нь хүний туршлагад биеллээ олж, хүний эрэл хайгуулаар илэрхийлэгддэг. Тиймээс хийгдсэн ажлаас ямар нэг зүйл Бурханы илэрхийлэл үү, эсвэл хүний илэрхийлэл үү гэдэг нь илэрхий болдог. Үүнийг Бурхан Өөрөө тайлбарлах хэрэггүй, хүн гэрчлэл хийхээр чармайх ч шаардлагагүй; түүнчлэн Бурхан Өөрөө ямар нэг хүнийг дарангуйлах хэрэггүй. Энэ бүхэн нь төрөлхийн илчлэл болон гарч ирдэг; энэ нь албадан тулгах юм уу хүн хөндлөнгөөс оролцож чадах зүйл биш. Хүний үүргийг илэрхийллээр нь дамжуулан мэдэж болох ба ямар нэгэн нэмэлт туршлагын ажил хийхийг хүмүүсээс шаарддаггүй. Хүний бүх мөн чанар үүргээ гүйцэтгэж байхад нь илчлэгдэж болдог байхад Бурхан ажлаа хийх зуураа төрөлх зан чанараа илэрхийлж чаддаг. Хэрвээ энэ нь хүний ажил мөн бол үүнийг нуун далдалж болдоггүй. Харин Бурханы ажил бол Бурханы зан чанарыг хэн нэгэн хүн далдлах бүр ч боломжгүй, хүн үүнийг хянах бүр ч боломжгүй. Нэг ч хүнийг Бурхан гэж хэлж болохгүй, мөн тэдний ажил болон үгийг ариун гэж харах юм уу хувиршгүй гэж үзэж болохгүй. Бурхан Өөрийгөө махбодоор хувцасласнаас болоод Түүнийг хүн гэж хэлж болох боловч Түүний ажлыг хүний ажил юм уу хүний үүрэг гэж үзэж болохгүй. Түүнчлэн, Бурханы айлдвар болон Паулын захиаг адилтган үзэж болохгүй, Бурханы шүүлт, гэсгээлт болон хүний удирдамжийн үгсийг эн зэрэгцүүлэн ярьж ч болохгүй. Тиймээс Бурханы ажлыг хүний ажлаас ялгадаг зарчмууд байдаг. Тэдгээрийг ажлын цар хүрээ, эсвэл түр зуурын бүтээмжийнх нь дагуу биш, харин мөн чанараар нь ялгадаг. Энэ сэдвийн тухай ихэнх хүмүүс зарчмын алдаа гаргадаг. Учир нь хүн өөрсдийн хүрч чадах гадна талыг л хардаг байхад Бурхан, хүн төрөлхтний махан биеийн нүдээр ажиглах аргагүй мөн чанарыг хардаг. Хэрвээ чи Бурханы үг болон ажлыг ердийн хүний үүрэг гэж авч үзээд хүний томоохон цар хүрээтэй ажлыг хүний гүйцэтгэдэг үүрэг гэхийн оронд махбодоор хувцасласан Бурханы ажил гэж үзвэл зарчмын хувьд андуурч байгаа бус уу? Хүний захиа болон намтрыг, зөвхөн Ариун Сүнсний ажлын суурин дээр л амархан бичиж болно. Харин Бурханы айлдвар

болон ажлыг хүн амархан гүйцэтгэж, эсвэл хүний мэргэн ухаан, бодол сэтгэхүйгээр биелүүлж чадахгүй, хүмүүс тэдгээрийг судалж шинжилснийхээ дараа нэгд нэггүй тайлбарлаж ч чадахгүй. Хэрвээ зарчмын эдгээр асуудал та нарт ямар ч хариу үйлдэл төрүүлэхгүй бол итгэл чинь төдийлөн жинхэнэ, бас цэвэр биш гэдэг нь илэрхий юм. Та нарын итгэл тодорхойгүй байдлаар дүүрэн, будилж төөрөлдсөн, зарчимгүй гэж хэлж л болно. Бурхан, хүн хоёрын хамгийн гол чухал асуудлыг ч ойлгодоггүй иймэрхүү итгэл тэр чигтээ ухан ойлгох чадвараар дутмаг итгэл бус уу? Паул яаж бүхий л түүхэн туршид ашиглагдсан цорын ганц хүн байж болох юм бэ? Тэр яаж чуулганы төлөө ажиллаж байсан цорын ганц хүн байж болох юм бэ? Тэр яаж чуулганuудыг дэмжихийн тулд юм бичсэн цорын ганц хүн байж болох юм бэ? Энэ хүмүүсийн ажлын цар хүрээ, нөлөөлөл, тэр ч бүү хэл, ажлынх нь үр дүнгээс үл хамааран, тийм ажлын зарчим, мөн чанар бүгд төстэй бус уу? Энэ нь Бурханы ажлаас шал өөр байдаг бус уу? Бурханы ажлын үе шат бүрийн хооронд тодорхой ялгаа байдаг бөгөөд Түүний ажлын олон арга барил бүхэлдээ адилхан байдаггүй ч гэсэн тэдгээр нь бүгд ганцхан мөн чанар, эх сурвалжтай байдаг бус уу? Иймээс хэрвээ хүн одоо ч эдгээр зүйлийн талаар тодорхой мэдэхгүй байгаа бол түүнд эрүүл ухаан дэндүү дутмаг байна. Эдгээр үгийг уншсаныхаа дараа ч Паулын захиа бол ариун, хувиршгүй бөгөөд ямар нэг сүнслэг хүний намтраас өөр гэж хэлсээр байгаа бол тэр хүний эрүүл ухаан дэндүү хэвийн бус, мөн тийм хүн ямар ч эрүүл ухаангүй, хоосон онолын мэргэжилтэн гэдэг нь эргэлзээгүй. Чи Паулыг шүтдэг байсан ч бодит баримтуудыг мушгин гуйвуулж, эсвэл үнэний оршин тогтнолыг няцаахын тулд түүнийг гэх халуун сэтгэлээ ашиглаж болохгүй. Үүнээс гадна, Миний хэлсэн зүйл яавч Паулын бүх ажил болон захиаг галдан шатааж, эсвэл лавлагаа болох үнэ цэнийг нь бүрэн үгүйсгэж байгаа юм биш. Ямартай ч эдгээр үгийг хэлж байгаа Миний санаа зорилго бол та нарыг бүх зүйл болон хүний талаар зүй зохистой ойлголт, үндэслэлтэй үнэлгээтэй болгох явдал: Зөвхөн энэ л хэвийн эрүүл ухаан юм; энэ нь л үнэнийг эзэмшдэг зөв шударга хүмүүсийн зэвсэглэх учиртай зүйл билээ.

АМЖИЛТ ЭСВЭЛ БҮТЭЛГҮЙТЭЛ НЬ ХҮНИЙ АЛХДАГ ЗАМААС ХАМААРДАГ

Ихэнх хүмүүс ирээдүйн хүрэх газрынхаа төлөө, эсвэл түр зуурын зугаа цэнгэлийн төлөө Бурханд итгэдэг. Ямар ч харьцалт туулаагүй хүмүүсийн хувьд тэнгэрт орохын төлөө, шагнал хүртэхийн төлөө Бурханд итгэдэг. Тэд төгс болгуулахын төлөө, эсвэл Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхийн төлөө Бурханд итгэдэггүй. Өөрөөр хэлбэл, ихэнх хүн өөрсдийн хариуцлагыг биелүүлэхийн тулд юм уу өөрсдийн үүргийг гүйцэтгэхийн тулд Бурханд итгэдэггүй. Утга учиртай амьдралаар амьдрахын тулд Бурханд итгэдэг хүмүүс ховорхон, мөн хүн амьд

байгаа тул Бурханыг хайрлах ёстой, учир нь энэ нь тун жам ёсны, үндэслэлтэй бөгөөд хүний хүлээсэн үүрэг мөн гэж итгэдэг хүмүүс байдаггүй. Ийм маягаар, хэдийгээр өөр өөр хүмүүс өөрсдийн хувийн зорилгыг эрэлхийлдэг боловч тэдний эрэл хайгуулын зорилго болон үүний ар дахь сэдэл бүгд төстэй байдгаас гадна ихэнхийнх нь сүсэг бишрэлийн бай ихээхэн адил байдаг. Сүүлийн хэдэн мянган жилийн турш олон итгэгч нас барсан ба олон итгэгч нас бараад дахин төрсөн. Бурханыг эрж хайдаг хүн ердөө ганц хоёроор зогсохгүй, тэр ч бүү хэл нэг, хоёр мянгаар ч зогсохгүй, гэхдээ энэ хүмүүсийн ихэнх нь өөрсдийн хэтийн ирээдүй, эсвэл ирээдүйн сайн сайхан итгэл найдварынхаа араас хөөцөлддөг. Христэд үнэнч хүмүүс ховорхон. Олон үнэн сүсэгт итгэгч өөрсдийн урхи торонд ороогдон нас нөгчсөн, түүнчлэн ялалт авчирсан хүмүүсийн тоо ч өчүүхэн бага. Өнөөг хүртэл, хүмүүсийн бүтэлгүйтдэг шалтгаан, эсвэл ялалтын нууцыг хүмүүс мэдэхгүй хэвээр байгаа. Христийг эрж хайхад донтсон хүмүүс одоо ч сэхээрээгүй, эдгээр нууцын үнэн мөнийг олж мэдээгүй, учир нь тэд ердөө мэддэггүй. Хэдий тэд эрэл хайгуулдаа уйгагүй хүчин чармайлт гаргадаг ч тэдний алхдаг зам нь амжилтын зам биш, харин өмнөх үеийнхнийх нь нэгэнтээ алхаж байсан бүтэлгүйтлийн зам юм. Ийм маягаар, хэрхэн эрж хайснаас үл хамааран тэд харанхуй руу хөтөлдөг замаар алхдаггүй гэж үү? Тэдний олж авдаг зүйл гашуун үр жимс биш гэж үү? Өнгөрсөн үед амжилтад хүрсэн хүмүүсийг дуурайдаг хүмүүст эцэстээ зол завшаан тохиолдох уу, эсвэл гай гамшиг тохиолдох уу гэдгийг урьдчилан таамаглахад хэцүү. Тэгвэл бүтэлгүйтсэн хүмүүсийн мөрийг даган эрж хайдаг хүмүүсийн хувьд хэчнээн дор байх вэ? Тэд бүр ч их бүтэлгүйтэх боломжтой бус уу? Тэдний алхдаг замд ямар үнэ цэн байх билээ? Тэд цагаа дэмий үрж байгаа бус уу? Хүмүүс эрэл хайгуулдаа амжилтад хүрэх, эсвэл бүтэлгүйтэхээс үл хамааран, товчхондоо үүнд шалтгаан байдаг ба тэдний амжилт эсвэл бүтэлгүйтэл нь дур зоргоороо эрж хайснаар тодорхойлогддог биш юм.

Хүний Бурханд итгэх итгэлийн хамгийн үндсэн шаардлага нь үнэнч шударга зүрх сэтгэлтэй байж, өөрийгөө бүрэн зориулж, үнэхээр дуулгавартай байх явдал юм. Хүний хувьд, жинхэнэ итгэлийн хариуд бүх амьдралаа өгч, үүгээр дамжуулан бүхий л үнэнийг олж авч, Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэх нь хамгийн хэцүү байдаг. Энэ нь бүтэлгүйтдэг хүмүүсийн хүршгүй зүйл бөгөөд Христийг олж чаддаггүй хүмүүсийн хувьд бүр ч хүршгүй юм. Хүн өөрийгөө Бурханд бүрэн зориулахдаа тийм ч сайн биш учраас, Бүтээгчийн өмнө үүргээ биелүүлэхийг хүсдэггүй учраас, үнэнийг харсан ч үүнээс зайлсхийж, өөрийн замаар явдаг учраас, үргэлж бүтэлгүйтсэн хүмүүсийн замыг даган эрж хайдаг учраас, мөн Тэнгэрийг үргэлж эсэргүүцдэг учраас дандаа бүтэлгүйтэж, Сатаны заль мэхэнд үргэлж автаж, өөрийнхөө урхи торонд ордог. Хүн Христийг мэддэггүй учраас, үнэнийг ойлгож, туулахдаа чадамгай биш учраас, Паулыг дэндүү их шүтэж, тэнгэрт хэтэрхий их шунадаг учраас, өөрт нь дуулгавартай байхыг Христээс үргэлж шаардаж, Бурханд тушаадаг учраас тэр агуу хүмүүс болон дэлхий ертөнцийн эрээн барааныг туулсан

хүмүүс мөн л үхдэг бөгөөд Бурханы гэсгээлт дунд насан эцэслэдэг. Тийм хүмүүс эмгэнэлт үхлээр үхдэг ба тэдний үр дагавар буюу үхэл нь үндэслэлгүй биш юм гэж л Би хэлж чадна. Тэдний бүтэлгүйтэл нь Тэнгэрийн хуулинд бүр ч илүү тэвчишгүй биш гэж үү? Үнэн нь хүний ертөнцөөс үүддэг боловч хүмүүсийн дундах үнэнийг Христ дамжуулдаг. Энэ нь Христээс буюу Бурханаас Өөрөөс нь үүсэн гардаг ба хүний хүрч чадах зүйл биш. Гэхдээ Христ зөвхөн үнэнээр л хангадаг; үнэний төлөөх эрэл хайгуулдаа хүн амжилттай байх эсэхийг шийдэхийн тулд Тэр ирдэггүй. Тиймээс үнэн дэх амжилт, эсвэл бүтэлгүйтэл нь бүгд хүний эрэл хайгуулаас хамаардаг. Хүн үнэнд амжилт олох уу, эсвэл бүтэлгүйтэх үү гэдэг нь хэзээ ч Христтэй хамаатай байгаагүй, харин энэ нь хүний эрэл хайгуулаар тодорхойлогддог. Хүний хүрэх газар, түүний амжилт, эсвэл бүтэлгүйтлийг Бурханд хариуцуулж, Бурханд Өөрт нь үүрүүлж болохгүй, учир нь энэ бол Бурханы Өөрийн асуудал биш, харин Бурханы бүтээлүүдийн биелүүлэх ёстой үүрэгтэй шууд холбоотой. Ихэнх хүмүүс Паул, Петр хоёрын эрэл хайгуул болон хүрэх газрын талаар бага зэрэг мэддэг ч Петр, Паул хоёрын үр дүнгээс өөрийг мэддэггүй ба Петрийн амжилтын ар дахь нууцыг, эсвэл Паулыг бүтэлгүйтэхэд хүргэсэн дутагдлыг мэддэггүй. Иймээс хэрвээ та нар тэдний эрэл хайгуулын мөн чанарыг нэгд нэггүй ойлгож огт чадахгүй бол олонхын чинь эрэл хайгуул ч бас бүтэлгүйтнэ, та нараас цөөн хэд нь амжилтад хүрсэн ч гэсэн Петртэй эн тэнцүү байж мөн л чадахгүй. Хэрвээ эрэл хайгуулын чинь зам зөв бол амжилтад хүрэх найдвар чамд байна; хэрвээ үнэнийг эрж хайн явж байгаа зам чинь буруу бол чи үүрд амжилтад хүрч чадахгүй байх ба Паултай адил төгсгөлтэй тулгарна.

Петр төгс болгуулсан хүн байв. Тэрээр гэсгээлт, шүүлт туулж, Бурханыг гэх цэвэр хайрыг олж авсныхаа дараа л бүрэн дүүрэн төгс болгуулсан; түүний алхсан зам нь төгс болгуулах зам байлаа. Өөрөөр хэлбэл, Петрийн алхсан зам бүр эхнээсээ л зөв байсан ба Бурханд итгэх сэдэл нь зөв байсан, иймээс тэр төгс болгуулсан нэгэн болж, урьд өмнө нь хүний хэзээ ч алхаж байгаагүй шинэ замаар явсан юм. Харин Паулын алхсан зам эхнээсээ л Христийг эсэргүүцэх зам байсан бөгөөд Ариун Сүнс түүнийг ашиглаж, билиг авьяас, бүх давуу талыг нь Өөрийн ажилд ашиглахыг хүссэн учраас л тэр Христийн төлөө хэдэн арван жил ажилласан билээ. Тэрээр ердөө л Ариун Сүнсний ашигласан хүн байсан бөгөөд Есүс түүний хүн чанарт наашгай хандсанаас болж биш, харин билиг авьяасаасаа болж ашиглагдсан юм. Тэр цохигдсон учраас л Есүсийн төлөө ажиллаж чадсан болохоос биш, үүнийг хийхдээ баяртай байсан юм биш. Ариун Сүнсний гэгээрэл, удирдамжаас болж тэр ийм ажил хийж чадсан бөгөөд хийсэн ажил нь түүний эрэл хайгуулыг юм уу хүн чанарыг яавч төлөөлөөгүй. Паулын ажил зарцын ажлыг төлөөлж байсан, өөрөөр хэлбэл, тэрээр элчийн ажил хийсэн юм. Харин Петр өөр байлаа: Тэр ч бас зарим нэг ажил хийсэн; энэ нь Паулын ажил шиг агуу байгаагүй ч тэрээр өөрийн оролтыг эрэлхийлэх зуураа ажилласан бөгөөд түүний ажил Паулын ажлаас өөр байв. Петрийн ажил нь Бурханы бүтээлийн үүргийг биелүүлсэн

явдал байсан юм. Тэр элчийн байр сууринаас ажиллаагүй, харин Бурханыг хайрлахаар эрэлхийлэнгээ ажилласан билээ. Ажлынх нь явцад Паулд бас хувийн эрэл хайгуул байсан: Түүний эрэл хайгуул гагцхүү ирээдүйн итгэл найдвар болон сайхан хүрэх газрын төлөөх хүслийнх нь төлөө байсан юм. Ажлынхаа үеэр тэр цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, мөн харьцалт, засалтыг ч хүлээн зөвшөөрөөгүй. Хийсэн ажил нь Бурханы хүслийг хангаж, хийсэн бүхэн нь Бурханд таалагдсаар байгаа цагт эцэстээ түүнийг шагнал хүлээж байгаа гэж итгэсэн. Түүний ажилд ямар ч хувийн туршлага байгаагүй—энэ нь бүхэлдээ ажиллахын төлөө хийгдсэн бөгөөд өөрчлөгдөх эрэл хайгуулын дунд хийгдээгүй. Түүний ажил дахь бүх юм наймаа байсан, харин Бурханы бүтээлийн үүрэг юм уу дуулгавартай байдлын алийг ч агуулаагүй. Өөрийнх нь ажлын явцад Паулын хуучин зан чанарт ямар ч өөрчлөлт гараагүй. Түүний ажил ердөө бусдад үйлчлэх явдал байсан ба зан чанарт нь өөрчлөлт гаргаж чадаагүй юм. Паул төгс болгуулалгүйгээр, мөн харьцалт туулалгүйгээр шууд ажилласан ба шагнал авах гэсэн сэдэлтэй байв. Петр бол өөр байлаа: Тэрээр засалт, харьцалт туулсан, цэвэршүүлэлт туулсан хүн байв. Петрийн ажлын зорилго болон сэдэл нь үндсэндээ Паулынхаас өөр байсан юм. Хэдийгээр Петр их хэмжээний ажил хийгээгүй ч зан чанарт нь олон өөрчлөлт гарсан ба эрж хайсан зүйл нь үнэн болон бодит өөрчлөлт байлаа. Түүний ажил зүгээр л гагцхүү ажлын төлөө хийгдээгүй. Паул хэдийгээр их ажил хийсэн ч энэ нь бүхэлдээ Ариун Сүнсний ажил байсан бөгөөд Паул энэ ажилд хамтран ажилласан хэдий ч үүнийг туулаагүй. Ариун Сүнс өөрөөр нь дамжуулж их ажил хийгээгүй учраас л Петр хавьгүй бага ажил хийсэн юм. Тэдний ажлын хэмжээ төгс болгуулсан эсэхийг нь тодорхойлоогүй; нэгнийх нь эрэл хайгуул шагнал авахын төлөө байсан, нөгөөгийнх нь Бурханы хүслийг хангалуун байлгахын тулд хайр татам дүр төрхийг амьдран харуулж чадах хэмжээнд Бурханыг гэх туйлын хайранд хүрч, Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхийн төлөө байсан юм. Гаднаа тэд өөр байсан, мөн чанар нь ч бас өөр байсан. Хэр их ажил хийсэнд нь үндэслээд тэдний хэн нь төгс болгуулсныг чи тодорхойлж чадахгүй. Петр Бурханыг хайрладаг нэгний дүрийг амьдран харуулахыг, Бурханыг дуулгавартай дагадаг нэгэн байхыг, харьцалт, засалтыг хүлээн зөвшөөрдөг нэгэн байхыг, Бурханы бүтээлийн хувиар үүргээ биелүүлдэг нэгэн байхаар эрэлхийлсэн. Тэрээр өөрийгөө Бурханд зориулж, өөрийгөө бүхэлд нь Бурханы гарт даатгаж, үхэх хүртлээ Түүнд дуулгавартай байж чадсан юм. Энэ нь түүний хийхээр шийдсэн зүйл, түүнчлэн түүний биелүүлсэн зүйл байлаа. Түүний төгсгөл эцэстээ яагаад Паулынхаас өөр байсны үндсэн шалтгаан нь энэ юм. Петрт Ариун Сүнсний хийсэн ажил нь түүнийг төгс болгохын төлөө байсан бөгөөд Паулд хийсэн ажил нь түүнийг ашиглахын төлөө байсан. Яагаад гэвэл, тэдний уг чанар болон эрэл хайгуулын талаарх үзэл бодол адилхан байгаагүй юм. Хоёулаа Ариун Сүнсний ажилтай байсан. Петр энэ ажлыг өөртөө хэрэгжүүлж, бас үүгээр бусдыг хангасан; харин Паул Ариун Сүнсний ажлыг бүхэлд нь бусдад өгөөд, өөрөө үүнээс юу ч олж аваагүй. Ийм маягаар Ариун Сүнсний

ажлыг маш олон жил туулсны дараа ч Паулд гарсан өөрчлөлт нь бараг байхгүйтэй адил байв. Тэрээр бараг төрөлх байдлаараа үлдсэн ба урьдын Паул хэвээрээ байлаа. Олон жилийн ажлын хүнд хэцүүг туулсныхаа дараа тэр ердөө хэрхэн “ажиллахыг” сурч, тэвчээртэй байж сурсан боловч түүний хуучин уг чанар—ихэд өрсөлддөг, ашиг хонжоонд шунадаг уг чанар нь хэвээр үлдсэн юм. Маш олон жил ажилласныхаа дараа тэрээр завхарсан зан чанараа мэдээгүй, хуучин зан чанараасаа ч салж чадаагүй бөгөөд эдгээр нь түүний ажлаас илт харагдсаар байв. Түүнд ердөө арай илүү ажлын туршлага байсан боловч тийм өчүүхэн туршлага нь дангаараа түүнийг өөрчилж чадаагүй ба оршин тогтнолын талаарх түүний үзэл бодлыг, эсвэл эрэл хайгуулынх нь ач холбогдлыг өөрчилж чадаагүй. Тэрээр Христийн төлөө олон жил ажиллаж, Эзэн Есүсийг дахин хэзээ ч хяхан хавчаагүй хэдий ч түүний зүрх сэтгэл дэх Бурханы талаарх мэдлэгт ямар ч өөрчлөлт гараагүй. Өөрөөр хэлбэл, тэр өөрийгөө Бурханд зориулахын тулд ажиллаагүй, харин ирээдүйн хүрэх газрынхаа төлөө албан хүчээр ажилласан гэсэн үг юм. Учир нь эхэндээ тэр Христийг хяхан хавчиж байсан бөгөөд Христэд дуулгавартай байгаагүй; тэрээр Христийг зориуд эсэргүүцдэг төрөлхийн тэрслүү хүн, мөн Ариун Сүнсний ажлын талаар ямар ч мэдлэггүй хүн байлаа. Өөрийнх нь ажил бараг дуусаж байх үед тэрээр Ариун Сүнсний ажлыг мэдэхгүй хэвээр байсан бөгөөд Ариун Сүнсний хүсэлд өчүүхэн төдий ч анхаарал хандуулалгүйгээр, зүгээр л зан авирынхаа дагуу дур зоргоороо үйлдсэн юм. Иймээс түүний уг чанар Христэд дайсагнаж байсан ба үнэнийг дуулгавартай дагаагүй. Ариун Сүнсний ажилд хаягдсан, Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, бас Христийг эсэргүүцдэг ийм хүн яаж аврагдаж чадах юм бэ? Хүн аврагдаж чадах уу, үгүй юу гэдэг нь хэр их ажил хийснээс, эсвэл хэр их зориулснаас хамаардаггүй, харин Ариун Сүнсний ажлыг мэддэг эсэхээр, үнэнийг хэрэгжүүлж чаддаг эсэхээр болон эрэл хайгуулын талаарх үзэл бодол нь үнэнтэй нийцдэг эсэхээр тодорхойлогддог.

Петр Есүсийг дагаж эхэлсний дараа төрөлхийн илчлэлүүд тохиолдсон хэдий ч уг чанартаа тэрээр анхнаасаа Ариун Сүнсэнд захирагдаж, Христийг эрж хайх хүсэлтэй нэгэн байсан юм. Тэрээр Ариун Сүнсэнд жинхэнээсээ дуулгавартай байв: Тэр нэр алдар, эд хөрөнгө хөөгөөгүй, харин үнэнд дуулгавартай байхаар зорьж байлаа. Петр хэдийгээр Христийг мэддэг гэдгээ гурван удаа үгүйсгэж, Эзэн Есүсийг сорьсон ч хүний тийм өчүүхэн сул тал нь түүний уг чанартай ямар ч холбоогүй байсан ба ирээдүйн эрэл хайгуулд нь нөлөөлөөгүй, мөн түүний сорилт антихристийн үйл байсан гэдгийг хангалттай баталж чадахгүй. Хүний хэвийн сул тал бол дэлхий дээрх бүх хүнд байдаг зүйл—Петр өөр байх ёстой гэж чи бодож байна уу? Петр хэд хэдэн тэнэг алдаа хийсэн учраас хүмүүс түүний талаар тодорхой үзэл бодол өвөрлөдөг бус уу? Паулын хийсэн бүх ажил, бичсэн бүх захидлаас болж хүмүүс Паулыг ихэд биширдэг бус уу? Хүн яаж хүний гол чанарыг нэвт харж чадах юм бэ? Үнэхээр эрүүл ухаантай хүмүүс тийм ялихгүй зүйлийг харж чадна биз дээ? Петрийн олон жилийн шаналгаат туршлага нь Библид

тэмдэглэгдээгүй хэдий ч Петрт бодитой туршлага байгаагүй, эсвэл Петр төгс болгуулаагүй гэдгийг энэ нь нотолдоггүй. Бурханы ажлыг хүн яаж бүрэн ухан ойлгож чадах юм бэ? Библи дэх бичвэрүүдийг Есүс биечлэн сонгоогүй, харин дараагийн үеийнхэн эмхэтгэсэн. Тийм болохоор Библид бичигдсэн бүхнийг хүний санаагаар сонгосон бус уу? Түүнчлэн Петр, Паул хоёрын төгсгөлийг захидлуудад тодорхой өгүүлээгүй, иймээс хүн өөрийн үзэмжээр, мөн өөрийн дур сонирхлоор Петр, Паул хоёрыг үнэлдэг. Паул маш их ажил хийсэн учраас, түүний “хувь нэмэр” асар их байсан учраас тэрээр олон нийтийн итгэлийг олсон. Хүн зөвхөн өнгөц байдалд анхаарал хандуулдаггүй гэж үү? Хүн яаж хүний гол чанарыг нэвт харах чадвартай байх юм бэ? Үүнээс гадна, Паул олон мянган жилийн турш шүтлэг бишрэлийн бай байсан болохоор түүний ажлыг хэн яаран үгүйсгэж зүрхлэх юм бэ? Петр ердөө л загасчин байсан, иймээс түүний хувь нэмэр яаж Паулынх шиг их байж чадах юм бэ? Тэдний оруулсан хувь нэмрийн тухайд бол Паул Петрээс өмнө шагнуулах ёстой байсан ба Паул Бурханы сайшаалыг хүртэхэд илүү тохирсон нэгэн байх ёстой байлаа. Паулд хандахдаа Бурхан ердөө л билиг авьяасаар нь дамжуулан түүнийг ажиллуулсан, харин Бурхан Петрийг төгс болгосон гэж хэн төсөөлж чадах билээ? Ямартай ч Эзэн Есүс бүр эхнээсээ л Петр, Паул хоёрын төлөө төлөвлөгөө зохиосон юм биш: Харин ч тэд төрөлхийн уг чанарынхаа дагуу төгс болгуулж, эсвэл ажилласан юм. Иймээс хүмүүсийн хардаг зүйл нь ердөө хүний гадаад талын хувь нэмэр байдаг байхад Бурханы хардаг зүйл нь хүний гол чанар, түүнчлэн эхнээсээ хүний эрэлхийлдэг зам болон хүний эрэл хайгуулын ар дахь сэдэл юм. Хүмүүс өөрсдийн үзлийн дагуу, өөрсдийн үзэмжээр хүнийг хэмждэг ч хүний эцсийн төгсгөл нь түүний харагдах байдлаар тодорхойлогддоггүй. Иймээс хэрвээ эхнээсээ дагадаг зам чинь амжилтын зам бөгөөд эрэл хайгуулын талаарх үзэл бодол чинь анхнаасаа зөв бол чи Петртэй адил; хэрвээ алхаж буй зам чинь бүтэлгүйтлийн зам бол ямар ч төлөөс төлсөн бай, хүрэх газар чинь Паулынхтай адилхан байх болно гэж Би хэлдэг. Ямар ч тохиолдолд, чиний хүрэх газар болон амжилтад хүрэх үү, бүтэлгүйтэх үү гэдэг чинь хоёулаа чиний зориулалтаас, эсвэл төлсөн төлөөсөөс биш, харин эрж хайж байгаа зам чинь зөв үү, үгүй юу гэдгээр тодорхойлогддог. Петр, Паул хоёрын мөн чанар, зорьсон зорилго өөр байсан; хүн эдгээр зүйлийг олж мэдэх чадваргүй бөгөөд Бурхан л тэдгээрийг бүхэлд нь мэдэж чадна. Учир нь Бурхан хүний гол чанарыг хардаг байхад хүн өөрийнхөө мөн чанарын талаар юу ч мэддэггүй. Хүн, хүний доторх мөн чанарыг юм уу бодит биеийн хэмжээг нь харах чадваргүй, тиймээс Паул, Петр хоёрын бүтэлгүйтэл болон амжилтын шалтгааныг тодорхойлох чадваргүй юм. Ихэнх хүн Петрийг биш, Паулыг шүтдэгийн шалтгаан нь Паул олон нийтийн ажлын төлөө ашиглагдсан ба хүн энэ ажлыг харж чаддаг тул хүмүүс Паулын “гавьяаг” хүлээн зөвшөөрдөг. Харин Петрийн туршлага хүнд харагддаггүй, түүний эрж хайсан зүйл хүний хувьд хүршгүй тул хүн Петрийг огт сонирхдоггүй.

Петр харьцалт, цэвэршүүлэлт туулснаар төгс болгуулсан. Тэрээр: “Би цаг ямагт Бурханы хүслийг хангалуун байлгах ёстой. Хийж байгаа бүхэндээ би зөвхөн

Бурханы хүслийг хангахаар эрж хайдаг ба гэсгээгдэж, шүүгдэж байсан ч үүнийг баяртайяа хийнэ” гэж хэлсэн юм. Петр өөрт байгаа бүхнийг Бурханд өгсөн ба түүний ажил, үг, бүхий л амьдрал тэр чигтээ Бурханыг хайрлахын төлөө байв. Тэр бол ариун байдлыг эрж хайдаг хүн байсан бөгөөд туршлагажих тусам түүний зүрх сэтгэлийн гүн дэх Бурханыг гэх хайр улам их болж байлаа. Харин Паул зөвхөн гадна талын ажил хийсэн бөгөөд хэдийгээр шаргуу ажилласан ч түүний ажил хөдөлмөр ажлаа зохих ёсоор хийж, улмаар шагнал авахын төлөө байсан юм. Ямар ч шагнал авч чадахгүй гэдгээ мэдэж байсан бол тэр өөрийн ажлыг орхих байв. Петр өөрийн зүрх сэтгэл доторх жинхэнэ хайрыг л анхаарч байсан бөгөөд тэр нь бодитой, мөн биелүүлж болохуйц зүйл байлаа. Тэр шагнал авах эсэх талаар анхааараагүй, харин өөрийнх нь зан чанар өөрчлөгдөж чадах эсэхийг анхаарсан. Паул бүр ч илүү шаргуу ажиллах талаар анхаарч, гадна талын ажил, зориулалт болон хэвийн хүмүүсийн туулдаггүй хоосон сургаалын талаар анхаарсан. Тэрээр зүрх сэтгэлийнхээ гүн дэх өөрчлөлтийг ч, Бурханыг гэх жинхэнэ хайрыг ч огт анхааараагүй. Петрийн туршлага нь Бурханыг гэх жинхэнэ хайр, жинхэнэ мэдлэгт хүрэхийн төлөө байв. Түүний туршлага нь Бурхантай илүү ойр дотно харилцаатай болж, бодитоор амьдран харуулахын төлөө байжээ. Паулын ажил нь Есүсийн даалгасан зүйлээс болсон ба өөрийн хүсэн эрмэлзэж байсан зүйлийг олж авахын төлөө байсан ч эдгээр нь өөрийнхөө талаарх болон Бурханы талаарх мэдлэгтэй нь хамаагүй байв. Түүний ажил гагцхүү гэсгээлт, шүүлтээс зугтахын төлөө байсан. Петрийн цэвэр ариун хайрыг эрж хайж, Паул зөвт байдлын титмийг эрж хайжээ. Петр Ариун Сүнсний ажлыг олон жил туулсан бөгөөд Христийн талаар бодитой мэдлэгтэй, түүнчлэн өөрийнхөө талаар гүн гүнзгий мэдлэгтэй байсан. Иймээс Бурханыг гэх түүний хайр цэвэр байв. Олон жилийн цэвэршүүлэлт нь Есүс болон амийн талаарх түүний мэдлэгийг дээшлүүлсэн ба түүний хайр нөхцөлгүй хайр, идэвх санаачилгатай хайр байсан, тэрээр хариуд нь юу ч гуйгаагүй, ямар нэг ашиг тус хүртэнэ гэж ч найдаагүй. Паул олон жилийн турш ажилласан мөртөө Христийн талаар асар их мэдлэг эзэмшээгүй бөгөөд өөрийнх нь талаарх түүний мэдлэг ч бас өчүүхэн бага байлаа. Түүнд Христийг гэх хайр ердөө байгаагүй ба түүний ажил, явсан замнал нь эцсийн нэр хүндийг олж авахын төлөө байсан. Түүний эрж хайсан зүйл хамгийн цэвэр хайр биш, харин хамгийн сайхан титэм байв. Тэр идэвхтэйгээр эрж хайгаагүй, харин ч идэвхгүй байсан; тэр үүргээ биелүүлээгүй, харин Ариун Сүнсний ажилд баригдсаныхаа дараа албан хүчээр эрж хайсан юм. Иймээс тэр бол шаардлага хангасан Бурханы бүтээл байсан гэдгийг эрэл хайгуул нь нотолдоггүй; харин Петр бол өөрийн үүргийг биелүүлж, Бурханы шаардлагыг хангасан бүтээл байлаа. Бурханд хувь нэмрээ оруулсан бүх хүн шагнал хүртэх ёстой ба хувь нэмэр хэдий чинээ их байна, Бурханы тааллыг хүртэх нь төдий чинээ баталгаатай гэж хүн боддог. Хүний үзэл бодлын мөн чанар нь арилжаа наймааны шинжтэй байдаг бөгөөд Бурханы бүтээлийн хувиар үүргээ биелүүлэхийн тулд идэвхтэйгээр эрж хайдаггүй. Бурханы хувьд, хүмүүс Бурханыг гэх жинхэнэ хайр болон Бурханд бүрэн

дуулгавартай байдлыг эрж хайх тусам, өөрөөр хэлбэл, Бурханы бүтээлийн хувиар үүргээ биелүүлэхээр эрж хайх тусам, Бурханы сайшаалыг төдий чинээ хүртэж чадна. Бурханы үзэл бодол бол анхдагч үүрэг болон байр сууриа сэргээхийг хүнээс шаардах явдал юм. Хүн бол Бурханы бүтээл, иймээс хүн Бурханд ямар нэгэн шаардлага тавьж даврах ёсгүй ба Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхээс өөрийг хийх ёсгүй. Паул, Петр хоёрын хүрэх газар хувь нэмрийнх нь хэмжээгээр биш, харин Бурханы бүтээлийн үүргээ биелүүлж чадсан эсэхээр хэмжигдсэн; тэдний хүрэх газар нь хэр их ажил хийсэн, эсвэл бусад хүмүүс тэднийг хэрхэн үнэлсний дагуу биш, харин анхнаасаа юу эрж хайснаар нь тодорхойлогдсон. Иймээс Бурханы бүтээлийн хувиар өөрийн үүргийг идэвхтэйгээр биелүүлэхээр хичээх нь амжилтад хүрэх зам; Бурханыг гэх жинхэнэ хайрын замыг эрж хайх нь хамгийн зөв зам; хуучин зан чанараа өөрчилж, Бурханыг гэх цэвэр хайрыг эрж хайх нь амжилтад хүрэх зам юм. Амжилтад хүрэх ийм зам нь Бурханы бүтээлийн анхдагч үүргээ, түүнчлэн анхдагч дүр төрхөө сэргээх зам юм. Энэ нь сэргэлтийн зам бөгөөд түүнчлэн эхнээсээ эцэс хүртэлх Бурханы бүх ажлын зорилго билээ. Хэрвээ хүний эрэл хайгуулд хувийн хэмжээлшгүй шаардлага болон зохисгүй хүсэл эрмэлзэл нь холилдвол үүгээр хүрэх үр дүн хүний зан чанарыг өөрчилж чадахгүй. Энэ нь сэргэлтийн ажилтай зөрөлддөг бөгөөд Ариун Сүнсний хийдэг ажил биш гэдэг нь эргэлзээгүй тул ийм төрлийн эрэл хайгуулыг Бурхан хүлээн зөвшөөрдөггүй гэдгийг нотолдог. Бурханы хүлээн зөвшөөрдөггүй эрэл хайгуул ямар ач холбогдолтой байх юм бэ?

Паулын хийсэн ажил хүний өмнө харагдсан, харин зүрх сэтгэлийнх нь гүн дэх Бурханыг гэх хайр хэр цэвэр байсан, Бурханыг хэр их хайрласан бэ гэдэг нь хүний харж чадахгүй зүйл юм. Хүн түүний хийсэн ажлыг л харж чаддаг ба түүнийг Ариун Сүнс гарцаагүй ашиглаж байсан гэдгийг л мэддэг тул чуулгануудыг хангаж чаддаг байсан болохоор Паул Петрээс илүү дээр байсан, ажил нь илүү их байсан гэж боддог. Петр хувийн туршлагадаа л анхаарч, ховорхон ажлынхаа явцад цөөн хэдэн хүнийг л олж авсан. Түүний цөөн хэдхэн, бараг хүн мэдэхгүй захидал байдаг боловч зүрх сэтгэлийнх нь гүн дэх Бурханыг гэсэн хайр хэр их байсныг хэн мэдэх билээ? Паул өдөр бүр Бурханы төлөө ажилласан: Хийх ажил байгаа л бол тэр хийсэн. Ийм маягаар титмийг авч, Бурханыг хангалуун байлгаж чадна гэж түүнд санагдсан, гэхдээ ажлаараа дамжуулан өөрийгөө өөрчлөх арга замыг эрж хайгаагүй. Петр амьдралдаа Бурханы хүслийг хангаагүй л бол сэтгэл нь тавгүйтдэг байв. Бурханы хүслийг хангаагүй л бол тэр харуусаж, Бурханы зүрх сэтгэлийг хангалуун байлгахаар чармайж чадах тохиромжтой арга замыг эрж хайдаг байлаа. Өөрийнхөө амьдралын хамгийн бага, хамгийн ялихгүй талуудад хүртэл тэрээр Бурханы хүслийг хангахыг өөрөөсөө шаардсаар байсан юм. Хуучин зан чанарынхаа тухайд бол тэр бүр ч хатуу чанга байж, үнэнд илүү гүнзгий орохын тулд өөртөө тавьсан шаардлагадаа бүр ч нарийн чанд хандаж байлаа. Паул зөвхөн өнгөц нэр төр, байр суурийг л эрж хайсан. Тэр хүмүүсийн өмнө онгирохоор хичээсэн бөгөөд амийн оролтод илүү гүнзгий

орохоор эрж хайгаагүй. Тэрээр бодит байдал биш, хоосон номлолыг л анхаарч байв. “Паул Бурханы төлөө маш их ажил хийсэн, гэтэл Бурхан яагаад түүнийг дурсан санадаггүй юм бэ? Петр Бурханы төлөө багахан ажил гүйцэтгэсэн, чуулгануудад их хувь нэмэр оруулаагүй, тэгвэл Бурхан яагаад түүнийг төгс болгосон юм бэ?” гэж зарим хүн хэлдэг. Петр Бурханыг тодорхой хэмжээнд хайрласан бөгөөд үүнийг Бурхан шаардсан; зөвхөн ийм хүмүүс л гэрчлэлтэй байдаг. Тэгвэл Паул ямар вэ? Паул Бурханыг ямар хэмжээнд хайрласан бэ? Паулын ажил юуны төлөө байсан бэ? Мөн Петрийн ажил юуны төлөө байсан бэ? Петр тийм ч их ажил хийгээгүй, гэхдээ түүний зүрх сэтгэлийн гүнд юу байсныг чи мэдэх үү? Паулын ажил чуулганууды хангаж, чуулганууды дэмжихтэй хамаатай байв. Петрийн туулсан зүйл бол өөрийнх нь амь зан чанарын өөрчлөлт байсан; тэрээр Бурханыг гэх хайрыг туулсан юм. Чи тэдний мөн чанар дахь ялгааг мэдсэн болохоор эцсийн эцэст хэн нь үнэхээр Бурханд итгэснийг болон хэн нь Бурханд үнэхээр итгээгүйг харж чадна. Тэдний нэг нь Бурханыг үнэхээр хайрласан, нөгөө нь Бурханыг үнэхээр хайрлаагүй; нэг нь зан чанартаа өөрчлөлт гаргасан, нөгөө нь тэгээгүй; нэг нь даруухнаар үйлчилсэн ба хүмүүст амар анзаарагдаагүй, харин нөгөөх нь хүмүүсээр шүтэгдсэн, агуу нэр хүндтэй байсан; нэг нь ариун байдлыг эрж хайсан, нөгөөх нь тэгээгүй, хэдий тэр бузар биш байсан ч цэвэр хайрыг эзэмшээгүй; нэг нь жинхэнэ хүн чанартай, нөгөө нь тийм биш байсан; нэг нь Бурханы бүтээлийн эрүүл ухааныг эзэмшсэн, нөгөөх нь тэгээгүй. Энэ нь Паул, Петр хоёрын мөн чанар дахь ялгаа юм. Петрийн алхсан зам нь амжилтын зам байсан, бас хэвийн хүн чанарыг сэргээж, Бурханы бүтээлийн үүргээ сэргээх зам байсан. Петр амжилттай бүх хүнийг төлөөлдөг. Паулын алхсан зам нь бүтэлгүйтлийн зам бөгөөд өнгөц төдий захирагдаж, өөрсдийгөө зарлагаддаг, Бурханыг жинхэнээсээ хайрладаггүй бүх хүнийг төлөөлдөг. Паул үнэнийг эзэмшээгүй бүх хүнийг төлөөлдөг. Бурханд итгэх итгэлдээ Петр бүх зүйл дээр Бурханыг хангалуун байлгахаар эрж хайсан ба Бурханаас ирсэн бүхэнд дуулгавартай хандахаар хичээсэн. Тэрээр өчүүхэн төдий ч гомдолгүйгээр гэсгээлт, шүүлт, түүнчлэн цэвэршүүлэлт, гай зовлон, амьдралынхаа гачигдлыг хүлээн авч чадсан бөгөөд эдгээрийн юу ч Бурханыг гэх хайрыг нь өөрчилж чадаагүй. Энэ нь Бурханыг гэсэн туйлын хайр байсан бус уу? Бурханы бүтээлийн үүргийг биелүүлсэн бус уу? Гэсгээлт, шүүлт, гай зовлонгийн үед ч чи үргэлж үхэх хүртлээ дуулгавартай байж чадах бөгөөд энэ нь Бурханы бүтээлийн хүрэх ёстой зүйл, мөн Бурханыг гэх хайрын цэвэр ариун байдал юм. Хэрвээ хүн ийм түвшинд хүрч чадах юм бол Бурханы бүтээл байхад тохирох бөгөөд Бүтээгчийн хүслийг үүнээс илүү хангалуун байлгах юу ч үгүй. Чи Бурханы төлөө ажиллаж чаддаг гэж төсөөл, гэхдээ чи Бурханд дуулгавартай ханддаггүй ба Бурханыг үнэхээр хайрлах чадваргүй. Ийм маягаар чи Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхгүйгээр үл барам Бурханаар яллагдана, учир нь чи үнэнийг эзэмшдэггүй, Бурханд дуулгавартай байх чадваргүй, Бурханд дуулгаваргүй хүн юм. Чи Бурханы төлөө ажиллах талаар л анхаардаг бөгөөд үнэнийг хэрэгжүүлэх, эсвэл өөрийгөө

мэдэх талаар анхаардаггүй. Бүтээгчийг ойлгодоггүй, мэддэггүй бөгөөд Бүтээгчид дуулгавартай байдаггүй, мөн Түүнийг хайрладаггүй. Чи бол төрөлхийн Бурханд дуулгаваргүй хүн, иймээс тийм хүмүүсийг Бүтээгч хайрладаггүй.

Зарим хүн: “Паул тоймгүй их хэмжээний ажил хийсэн ба чуулгануудын төлөө асар их ачаа үүрч, маш их хувь нэмэр оруулсан. Паулын арван гурван захидал нь Нигүүлслийн эрин үеийн 2,000 жилд дэмжлэг үзүүлсэн ба Дөрвөн Сайн Мэдээний дараа ордог. Түүнтэй эн зэрэгцэж чадах хэн байх юм бэ? Иоханы Илчлэлийг хэн ч тайлж чаддаггүй байхад Паулын бичсэн захидлууд амиар хангадаг, түүний хийсэн ажил чуулгануудад ач тустай байсан. Өөр хэн ийм зүйлийг биелүүлж чадах вэ? Тэгэхэд Петр ямар ажил хийсэн юм бэ?” гэдэг. Хүн бусдыг хувь нэмрийнх нь дагуу хэмждэг. Бурхан хүнийг хэмжихдээ уг чанарынх нь дагуу ханддаг. Амийг эрж хайдаг хүмүүсийн дундаас Паул өөрийнхөө голчанарыг мэддэггүй хүн байсан. Тэрээр огтхон ч даруухан, дуулгавартай байгаагүй, Бурханыг эсэргүүцдэг мөн чанараа ч мэддэг байгаагүй. Иймээс тэрээр нарийн ширийн туршлага туулаагүй хүн байсан бөгөөд үнэнийг хэрэгжүүлдэггүй хүн байлаа. Харин Петр өөр байжээ. Тэр өөрийн дутагдал, сул талыг болон Бурханы бүтээлийн хувиар өөрийн завхарсан зан чанарыг мэддэг байсан тул зан чанараа өөрчилж чадах хэрэгжүүлэлтийн замтай байв; тэрээр зөвхөн хоосон сургаалтай ч бодит байдалгүй хүмүүсийн нэг байгаагүй юм. Өөрчлөгддөг хүмүүс бол аврагдсан шинэ хүмүүс бөгөөд үнэнийг эрэлхийлэхэд тэнцдэг хүмүүс юм. Өөрчлөгддөггүй хүмүүс нь төрөлхийн хоцрогдмол хүмүүст харьяалагддаг; тэд бол аврагдаагүй хүмүүс, өөрөөр хэлбэл, Бурханы жигшин голдог хүмүүс билээ. Тэдний ажил хэчнээн их байсан ч тэднийг Бурхан санахгүй. Чи үүнийг өөрийнхөө эрэл хайгуултай харьцуулах үед эцсийн эцэст Петр шиг хүн үү, Паул шиг хүн үү гэдэг чинь илэрхий байх учиртай. Хэрвээ чиний эрэл хайгуулд ямар ч үнэн байхгүй хэвээр бол, мөн өнөөдөр ч гэсэн чи Паул шиг биеэ тоосон, эрээ цээргүй, уран ярьж, бардамнадаг хэвээр бол бүтэлгүй өөдгүй хүн гэдэг чинь эргэлзээгүй юм. Хэрвээ чи Петр шиг эрж хайж, хэрэгжүүлэлт болон жинхэнэ өөрчлөлтийг эрэлхийлж, биеэ тоосон юм уу эрх дураараа биш, харин үүргээ биелүүлэхээр зорьдог бол ялалтад хүрч чадах Бурханы бүтээл байх болно. Паул өөрийн мөн чанарыг, эсвэл завхралыг мэдээгүй, дуулгаваргүй байдлаа бүр ч мэдээгүй. Тэрээр Христийг жигшүүртэйгээр эсэргүүцэж байснаа хэзээ ч дурдаагүй, мөн тийм ч их харамсаагүй. Тэрээр зөвхөн товч тайлбар тавьсан ба зүрх сэтгэлийнхээ гүнд Бурханд бүрэн захирагдаагүй. Хэдий тэр Дамаскийн замд хөсөр унасан боловч зүрх сэтгэлийн гүнээс өөрийгөө шинжлээгүй. Тэр ажиллаж байгаа төдийдөө л сэтгэл ханаж байсан бөгөөд өөрийгөө мэдэж, хуучин зан чанараа өөрчлөх нь хамгийн чухал асуудал гэдгийг анхаарч үзээгүй. Тэр ердөө үнэнийг ярьж байгаадаа, мөс чанараа тайтгаруулахын тулд бусдыг хангаж байгаадаа, өөрийгөө тайвшруулж, урьдын нүглээ уучлахын тулд Есүсийн шавь нарыг хавчихаа больсондоо сэтгэл хангалуун байсан. Түүний зорьсон зорилго нь ирээдүйн титэм болон түр зуурын ажлаас цаашгүй байсан, түүний зорьсон зорилго нь үлэмж элбэг

нигүүлсэл байсан. Тэрээр хангалттай үнэнийг эрж хайгаагүй, урьд нь ойлгоогүй байсан үнэн рүү илүү гүнзгий орохоор ч эрэлхийлээгүй. Иймээс өөрийнх нь талаарх түүний мэдлэгийг худлаа байсан гэж хэлж болох бөгөөд тэрээр гэсгээлт, шүүлтийг хүлээн зөвшөөрөөгүй. Тэр ажиллаж чаддаг байсан гэдэг нь өөрийн уг чанар, эсвэл мөн чанарыг мэдэж байсан гэсэн үг биш; тэрээр гадна талын хэрэгжүүлэлтэд л анхаарлаа төвлөрүүлж байв. Түүнчлэн, түүний зорьж байсан зүйл нь өөрчлөлт биш, харин мэдлэг байсан юм. Түүний ажил бүхэлдээ Дамаскийн замд Есүс харагдсаны үр дүн байлаа. Энэ нь анхнаасаа түүний хийхээр шийдсэн зүйл байгаагүй, мөн хуучин зан чанар нь засалтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон ажил ч байгаагүй. Тэр яаж ч ажилласан бай, хуучин зан чанар нь өөрчлөгдөөгүй, иймээс түүний ажил урьдын нүглийг нь цайруулж чадаагүй, харин тухайн үеийн чуулгануудад тодорхой үүрэг гүйцэтгэсэн төдий юм. Хуучин зан чанар нь өөрчлөгдөөгүй ийм хүн—өөрөөр хэлбэл, аврал хүртээгүй хүн бол бүр ч үнэнгүй хүн бөгөөд Эзэн Есүсээр хүлээн зөвшөөрөгдөх хүмүүсийн нэг болж яасан ч чадаагүй. Тэрээр Есүс Христийг гэх хайр, хүндлэлээр дүүрэн хүн биш, үнэнийг эрж хайхдаа чадамгай хүн ч биш бөгөөд бие махбодтой болохын нууцыг эрж хайсан хүн бүр ч биш байлаа. Тэр зүгээр л мушгин маргах чадвартай хүн байсан бөгөөд өөрөөсөө илүү дээр хэнд ч, эсвэл үнэнийг эзэмшсэн хэнд ч бууж өгдөггүй хүн байв. Тэр өөрийнх нь эсрэг байсан, эсвэл өөртэй нь дайсагнаж байсан хүмүүст юм уу үнэнд атаархан, агуу дүр төрхтэй, гүн гүнзгий мэдлэгтэй авьяаслаг хүмүүсийг илүүд үздэг байжээ. Харин үнэн замыг эрж хайдаг, үнэнээс өөр юуг ч анхаардаггүй ядуу дорд хүмүүстэй харилцах дургүй байсан ба оронд нь зөвхөн хоосон сургаал ярьдаг, өргөн их мэдлэг эзэмшсэн шашны байгууллагын ахмад хүмүүстэй харилцдаг байлаа. Тэрээр Ариун Сүнсний шинэ ажлыг огт хайрлаагүй ба Ариун Сүнсний шинэ ажлын хөдөлгөөнийг анхааараагүй. Харин ч ердийн үнэнээс илүү дээгүүр байсан ёс заншил, хоосон сургаал түүнд таалагддаг байв. Өөрийн төрөлх гол чанар болон эрж хайсан бүхий л зүйлээрээ тэр, Бурханы гэр дэх үнэнч зарц гэгдэх нь бүү хэл, үнэнийг эрж хайсан Христэд итгэгч гэж ч нэрлэгдэх эрхгүй, учир нь түүний хоёр нүүрт зан хэтэрхий их байсан ба дуулгаваргүй байдал нь дэндүү их байсан билээ. Хэдийгээр түүнийг Эзэн Есүсийн зарц гэдэг байсан ч тэр тэнгэрийн хаанчлалын хаалгаар ороход огт тохирохгүй, учир нь эхнээсээ эцэс хүртэлх түүний үйлдлийг зөв шударга гэж хэлж болохгүй. Түүнийг ердөө л хоёр нүүрт нэгэн, зөв шударга бусыг үйлдсэн атлаа бас Христийн төлөө ажилласан нэгэн гэж үзэж болно. Хэдийгээр түүнийг ёрын муу гэж хэлж болохгүй ч зөв шударга бусыг үйлдсэн хүн гэж нэрлэвээс зохилтой. Тэр ихээхэн ажил хийсэн ч хийсэн ажлынхаа хэмжээгээр үнэлэгдэх ёсгүй, харин ажлын чанар болон мөн чанараар л үнэлэгдэх ёстой. Зөвхөн ийм маягаар л энэ асуудлын учрыг нь олох боломжтой. Тэр үргэлж ингэж итгэдэг байсан: “Би ажиллах чадвартай, би ихэнх хүмүүсээс илүү дээр; би хэнээс ч илүүгээр Эзэний ачааг хайхардаг, хэн ч над шиг гүн гүнзгий гэмшдэггүй, учир нь их гэрэл над дээр тусаж, би их гэрлийг харсан, иймээс миний гэмшил өөр хэнийхээс ч илүү гүнзгий.” Тухайн

үед тэр зүрх сэтгэл дотроо ингэж бодож байсан юм. Өөрийнхөө ажлын төгсгөлд Паул: “Би тэмцэж, замналаа дуусгасан, надад зориулж зөвт байдлын титэм зэхэгдсэн байгаа” гэж хэлсэн. Түүний тэмцэл, ажил, замнал нь бүхэлдээ зөвт байдлын титмийн төлөө байсан ба тэр идэвхтэйгээр урагшлаагүй; хэдий тэр өөрийнхөө ажилд хааш яаш хандаагүй боловч түүний ажил ердөө л алдаагаа засаж залруулахын төлөө, мөс чанарынхаа буруушаалтыг болиулахын төлөө байсан гэж хэлж болно. Тэрээр аль болох хурдан ажлаа гүйцэлдүүлж, замналаа дуусгаж, тэмцэлдээ тэмцэхийг л хүсэж найдсан, ингэснээр хүсэн эрмэлзэж байсан зөвт байдлын титмээ илүү хурдан олж авч чадах байсан юм. Түүний хүсэн эрмэлзэж байсан зүйл нь өөрийн туршлага болон жинхэнэ мэдлэгээр Эзэн Есүстэй уулзах биш, харин Эзэн Есүстэй уулзах үедээ хийсэн ажилдаа тохирох шагналыг хүлээн авахын тулд ажлаа аль болох хурдан дуусгах явдал байв. Тэр өөрийгөө тайвшруулж, ирээдүйн титмээр наймаа хийхийн тулд өөрийн ажлыг ашигласан. Түүний эрж хайсан зүйл нь үнэн, эсвэл Бурхан биш, харин зөвхөн титэм байлаа. Тийм эрэл хайгуул яаж стандартад нийцэж чадах юм бэ? Түүний сэдэл, ажил, төлсөн төлөөс болон бүхий л хичээл чармайлтад нь түүний гайхалтай уран зөгнөл шингэсэн ба тэр бүхэлдээ өөрийн хүслийн дагуу л ажилласан. Бүхий л ажилдаа тэрээр төлөөс төлөхдөө өчүүхэн төдий ч дуртай байгаагүй; тэр зүгээр л наймаа хийж байв. Тэрээр үүргээ биелүүлэхийн тулд биш, харин наймааны зорилгод хүрэхийн тулд л дуртайяа хичээл чармайлт гаргасан. Тийм хүчин чармайлтад ямар нэгэн үнэ цэн байгаа юу? Түүний цэвэр бус хичээл чармайлтыг хэн сайшаах юм бэ? Тийм хичээл чармайлтыг хэн сонирхох юм бэ? Түүний ажил нь ирээдүйн төлөөх мөрөөдлөөр дүүрэн, гайхалтай төлөвлөгөөгөөр дүүрэн байсан ба хүний зан чанарыг өөрчлөх ямар ч замыг агуулаагүй. Түүний сайхан сэтгэлийн ихэнх нь дүр эсгэлт байсан; түүний ажил амиар хангаагүй, харин соёлч боловсон дүр үзүүлж байсан; энэ нь наймаа хийх явдал байсан юм. Ийм ажил нь анхдагч үүргээ сэргээх замд хүнийг хөтөлж яаж чадах юм бэ?

Петрийн эрж хайсан бүхэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байв. Тэр Бурханы хүслийг хангахаар эрэлхийлсэн ба зовлон зүдүүр, гай тотгорыг үл хайхран Бурханы хүслийг хангахад бэлэн байлаа. Бурханд итгэгчийн хувьд үүнээс илүү сайн эрэл хайгуул гэж үгүй. Паулын эрж хайсан зүйл өөрийнх нь махан бие, үзэл, төлөвлөгөө, арга ухаантай холилдсон. Тэр яавч шаардлага хангасан Бурханы бүтээл байгаагүй, Бурханы хүслийг хангахаар эрэлхийлсэн хүн ч байгаагүй. Петр Бурханы зохион байгуулалтад захирагдахаар хичээсэн ба хэдийгээр хийсэн ажил нь их биш байсан ч түүний эрэл хайгуулын ар дахь сэдэл болон алхсан зам зөв байсан; хэдий тэр олон хүнийг олж авч чадаагүй ч үнэний замыг эрэлхийлж чадсан юм. Үүнээс үүдэн, тэр бол шаардлага хангасан Бурханы бүтээл байсан гэж хэлж болно. Өнөөдөр чи ажилчин биш байлаа ч гэсэн, Бурханы бүтээлийн үүргийг биелүүлж, Бурханы бүх зохион байгуулалтад захирагдахаар эрэлхийлж чаддаг байх ёстой. Чи Бурханы хэлсэн бүхэнд дуулгавартай байж, бүх төрлийн гай зовлон, цэвэршүүлэлтийг туулж

чаддаг байх ёстой ба сул дорой хэдий ч зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлаж чаддаг байх ёстой. Өөрсдийн амийн төлөө хариуцлага үүрдэг хүмүүс Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхэд бэлэн байдаг ба тийм хүмүүсийн эрэл хайгуулд хандах үзэл бодол зөв байдаг. Эдгээр нь Бурханд хэрэгтэй хүмүүс юм. Хэрвээ чи их ажил хийж, бусад хүмүүс чамаас юм сурч авсан боловч чи өөрөө өөрчлөгдөөгүй, ямар ч гэрчлэл хийгээгүй, эсвэл ямар нэг жинхэнэ туршлагатай болоогүй, тийм болохоор амьдралынхаа эцэст ч гэсэн чиний хийсэн юу ч гэрчлэл хийгээгүй бол чи өөрчлөгдсөн хүн мөн үү? Чи үнэнийг эрж хайдаг хүн мөн үү? Тухайн үед Ариун Сүнс чамайг ашигласан ч чамайг ашиглах үедээ ажилд ашиглаж болох хэсгийг чинь л ашигласан бөгөөд ашиглагдаж болохгүй хэсгийг чинь Тэр ашиглаагүй. Хэрвээ чи өөрчлөгдөхөөр эрж хайсан бол ашиглагдах явцдаа аажмаар төгс болгуулах байсан. Гэсэн ч эцэстээ авхуулж чадах эсэхэд чинь Ариун Сүнс ямар ч хариуцлага хүлээдэггүй бөгөөд энэ нь эрэл хайгуулын чинь байдлаас хамаардаг. Чиний хувийн зан чанарт ямар ч өөрчлөлт байхгүй бол эрэл хайгуулд хандах үзэл бодол чинь буруугаас энэ нь болдог. Хэрвээ чи ямар ч шагнал хүртээгүй бол тэр нь өөрийн чинь асуудал бөгөөд чи өөрөө үнэнийг хэрэгжүүлээгүй, Бурханы хүслийг биелүүлж чаддаггүйгээс болдог. Иймээс чиний хувийн туршлагаас илүү чухал зүйл гэж юу ч үгүй, хувийн оролтоос чинь илүү шийдвэрлэх зүйл гэж юу ч үгүй! Зарим хүн эцэст нь, “Би Таны төлөө маш их ажил хийсэн, хэдийгээр биширмээр амжилт гаргаагүй байж болох ч би хичээнгүйлэн чармайсаар ирсэн. Та намайг зүгээр л тэнгэр лүү аваачиж, амийн жимс идүүлж болохгүй гэж үү?” хэмээн хэлнэ. Би ямар хүмүүсийг хүсдэгийг чи мэдэх ёстой; ариун бус хүмүүс хаанчлалд орохыг зөвшөөрөхгүй, ариун бус хүмүүс ариун газрыг балиартуулахыг зөвшөөрөхгүй. Хэдийгээр чи их ажил хийж, олон жилийн турш ажилласан ч эцэст нь өрөвдмөөр бузар хэвээр байвал Миний хаанчлалд орохыг хүсэх чинь Тэнгэрийн хуулиар тэвчишгүй юм! Дэлхий ертөнц бүтээгдсэнээс эхлээд өнөөдрийг хүртэл Надад ая тал зассан хүмүүст Би Миний хаанчлалд амархан орох боломжийг хэзээ ч олгож байгаагүй. Энэ бол тэнгэрийн дүрэм бөгөөд хэн ч үүнийг зөрчиж болохгүй! Чи амийг эрж хайх ёстой. Өнөөдөр, төгс болгуулах хүмүүс Петртэй адил төрлийнх юм: Тэд бол зан чанараа өөрчлөхөөр эрж хайдаг хүмүүс бөгөөд Бурханд гэрчлэл хийж, Бурханы бүтээлийн үүргээ биелүүлэхэд бэлэн байдаг хүмүүс юм. Тийм хүмүүс л төгс болгуулна. Хэрвээ чи зөвхөн шагнал горилоод, амь зан чанараа өөрчлөхөөр эрэлхийлдэггүй бол бүх хичээл чармайлт чинь талаар өнгөрнө—энэ бол өөрчлөгдөшгүй үнэн юм!

Петр, Паул хоёрын мөн чанар дахь ялгаанаас чи амийг эрэлхийлдэггүй бүх хүн дэмий хөдөлмөрлөдөг гэдгийг ойлгох ёстой! Чи Бурханд итгэж, Бурханыг дагадаг тул зүрх сэтгэлдээ Бурханыг хайрлах ёстой. Чи завхарсан зан чанараа хаях ёстой, Бурханы хүслийг биелүүлэхээр эрж хайх ёстой ба Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой. Чи Бурханд итгэж, Бурханыг дагадаг тул бүх зүйлийг Түүнд өргөн барих ёстой ба хувийн сонголт хийж, шаардлага тавих ёсгүй, мөн чи Бурханы хүслийг биелүүлэх ёстой. Чи бүтээгдсэн тул чамайг бүтээсэн Эзэнийг дуулгавартай

дагах ёстой, учир нь чи төрөлхөөсөө өөрийгөө захирч чадахгүй бөгөөд хувь заяагаа хянах ямар ч чадваргүй. Чи Бурханд итгэдэг хүн тул ариун байдал болон өөрчлөлтийг эрж хайх ёстой. Нэгэнт чи Бурханы бүтээл тул өөрийн үүргийг мөрдөж, байр сууриа хадгалах ёстой ба үүргээсээ хэтрэн гарах учиргүй. Энэ нь чамайг хязгаарлахын төлөө, эсвэл хоосон сургаалаар чамайг нухчин дарахын төлөө байдаггүй, харин энэ бол үүргээ биелүүлж чадах зам чинь бөгөөд зөв шударгыг үйлддэг бүх хүний хүрч чадах, хүрэх ёстой зам юм. Хэрвээ чи Петр, Паул хоёрын мөн чанарыг харьцуулбал хэрхэн эрж хайх ёстойгоо мэдэх болно. Петр, Паул хоёрын алхсан замын нэг нь төгс болгуулах зам, нөгөө нь таягдан хаягдах зам юм; Петр болон Паул нь хоёр өөр замыг төлөөлдөг. Хэдийгээр аль аль нь Ариун Сүнсний ажлыг хүлээн авч, хоёулаа Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг олж авч, аль аль нь Эзэн Есүсийн даалгасан зүйлийг хүлээн зөвшөөрсөн ч тус бүрээс нь гарсан үр дүн адилхан байгаагүй: Нэг нь үнэхээр үр дүнд хүрсэн ба нөгөө нь тэгээгүй. Тэдний мөн чанараас, хийсэн ажлаас, гаднаа илэрхийлж байсан зүйлээс, тэдний эцсийн төгсгөлөөс чи ямар замаар явах учиртайгаа, аль замыг нь сонгон алхах хэрэгтэйгээ ойлгох ёстой. Тэд гарцаагүй хоёр өөр замаар алхсан. Паул, Петр хоёр зам тус бүрийн хамгийн сайн төлөөлөгч байсан тул бүр анхнаасаа энэ хоёр замын үлгэр жишээ болсон. Паулын туршлагын гол зүйлс юу вэ, тэр яагаад үүндээ хүрээгүй вэ? Петрийн туршлагын гол зүйлс юу вэ, тэр хэрхэн төгс болгуулсан бэ? Хэрвээ чи тус бүрийнх нь анхаарч байсан зүйлсийг харьцуулах юм бол Бурхан яг ямар төрлийн хүнийг хүсдэг, Бурханы хүсэл юу болох, Бурханы зан чанар юу болох, ямар төрлийн хүн эцэстээ төгс болгуулах, мөн түүнчлэн ямар төрлийн хүн төгс болгуулж чадахгүйг мэднэ; мөн төгс болгуулах хүмүүсийн зан чанар ямар байх, төгс болгуулахгүй хүмүүсийн зан чанар ямар байхыг мэдэх бөгөөд мөн чанарын эдгээр асуудлыг Петр, Паул хоёрын туршлагаас харж болно. Бурхан бүх зүйлийг бүтээсэн, иймээс Тэр бүх бүтээлийг Өөрийн эрх мэдэл дор оруулж, Өөрийн эрх мэдэл дор захирагдуулдаг; Тэр бүх зүйлийг захирч, бүх зүйлийг Өөрийн гарт байлгана. Амьтан, ургамал, хүн төрөлхтөн, уул, гол нуур зэргийг оролцуулаад Бурханы бүх бүтээл бүгдээрээ Түүний эрх мэдэлд байх ёстой. Тэнгэр дэх болон газар дээрх бүх зүйл Түүний эрх мэдэл дор орох ёстой. Тэдэнд ямар ч сонголт байж болохгүй ба бүгд Түүний зохион байгуулалтад захирагдах ёстой. Үүнийг Бурхан зарлигдсан ба энэ нь Бурханы эрх мэдэл юм. Бурхан бүх зүйлийг захирдаг бөгөөд бүх зүйлийг цэгцэлж, жагсаан, Бурханы хүслийн дагуу төрлийнх нь дагуу ангилж, тус бүрийн байр суурийг нь оноодог. Хэчнээн том байх нь хамаагүй юу ч Бурханыг даван гарч чадахгүй, мөн бүх зүйл Бурханы бүтээсэн хүн төрөлхтөнд үйлчилдэг бөгөөд нэг ч зүйл Бурханд дуулгаваргүй байж, эсвэл Бурханд ямар нэгэн шаардлага тавьж зүрхэлдэггүй. Иймээс Бурханы бүтээл болохын хувьд хүн бас үүргээ биелүүлэх ёстой. Хүн бүх зүйлийн эзэн үү, эсвэл захирагч уу гэдгээс үл хамааран, бүх зүйлийн дундах хүний байр суурь хэчнээн өндөр байх нь хамаагүй тэр бол ердөө Бурханы эрх мэдэл дор буй өчүүхэн хүн, шалихгүй хүн, Бурханы бүтээлээс цаашгүй бөгөөд

Бурханаас дээгүүр байж хэзээ ч чадахгүй. Бурханы бүтээл болохын хувьд хүн Бурханы бүтээлийн үүргийг биелүүлэхээр эрж хайж, өөр сонголт хийлгүйгээр Бурханыг хайрлахаар хичээх ёстой, учир нь Бурхан хүний хайрыг хүртвээс зохино. Бурханыг хайрлахаар эрж хайдаг хүмүүс ямар нэг хувийн эрх ашгийг, эсвэл өөрсдийн хүсэн хүлээдэг зүйлийг эрж хайх ёсгүй; энэ нь эрэл хайгуулын хамгийн зөв зүйтэй арга барил юм. Хэрвээ эрж хайдаг зүйл чинь үнэн бол, хэрэгжүүлдэг зүйл чинь үнэн бол, олж авсан зүйл чинь зан чанарын өөрчлөлт бол чиний явж байгаа зам зөв байна. Хэрвээ эрж хайдаг зүйл чинь махан биеийн ерөөл бол, хэрэгжүүлдэг зүйл чинь чиний өөрийн үзлээс гарсан үнэн бол, мөн зан чанарт чинь ямар ч өөрчлөлт гараагүй, махбод дахь Бурханд огтхон ч дуулгаваргүй хандаж, тодорхой бус байдалтай амьдарсаар байгаа бол чиний эрж хайдаг зүйл чамайг гарцаагүй там руу аваачна, учир нь чиний алхдаг зам бүтэлгүйтлийн зам юм. Төгс болгуулах уу, таягдан хаягдах уу гэдэг чинь чиний өөрийн эрэл хайгуулаас хамаардаг, өөрөөр хэлбэл, амжилт эсвэл бүтэлгүйтэл нь хүний алхаж буй замаас хамаардаг.

БУРХАНЫ АЖИЛ БА ХҮНИЙ АЖИЛ

Хүний ажлын хэр их нь Ариун Сүнсний ажил, хэр их нь хүний туршлага байдаг вэ? Хүмүүс эдгээр асуултыг ойлгодоггүй хэвээр гэж хэлж болох ба үүний шалтгаан нь тэд Ариун Сүнсний ажлын зарчмыг ойлгодоггүй. “Хүний ажил” гэж хэлэхдээ Би мэдээж Ариун Сүнсний ажилтай хүмүүс буюу Ариун Сүнсний ашигладаг хүмүүсийг хэлж байна. Би хүний хүслээс гардаг ажлыг хэлээгүй, харин Ариун Сүнсний ажлын цар хүрээн дотор буй элчүүд, ажилчид, эгэл ах эгч нарын ажлыг хэлж байна. Энд “хүний ажил” гэдэг нь бие махбодтой болсон Бурханы ажлыг биш, харин хүмүүс дээр хийдэг Ариун Сүнсний ажлын цар хүрээ, зарчмыг хэлдэг. Эдгээр зарчим нь Ариун Сүнсний ажлын зарчим, цар хүрээ мөн боловч бие махбодтой болсон Бурханы ажлын зарчим, цар хүрээтэй адилгүй. Хүний ажилд хүний мөн чанар ба зарчим байдаг, харин Бурханы ажилд Бурханы мөн чанар ба зарчим бий.

Ариун Сүнсний урсгал дахь ажил нь Бурханы Өөрийн ажил ч бай, эсвэл ашиглагдаж буй хүмүүсийн ажил ч бай хамаагүй, Ариун Сүнсний л ажил юм. Бурханы Өөрийн мөн чанар бол Сүнс бөгөөд үүнийг Ариун Сүнс, эсвэл долоо дахин эрчимжсэн Сүнс гэж нэрлэж болно. Ямартай ч Тэд бол Бурханы Сүнс юм, харин Бурханы Сүнс өөр өөр эрин үед өөр өөр нэрээр нэрлэгдсэн. Гэхдээ Тэдний мөн чанар нэг хэвээр. Тиймээс, Бурханы Өөрийн ажил бол Ариун Сүнсний ажил; бие махбодтой болсон Бурханы ажил ч Ариун Сүнсний ажлаас өөрцгүй. Ашиглагдаж буй хүмүүсийн ажил ч бас Ариун Сүнсний ажил юм. Гэсэн ч Бурханы ажил бол Ариун Сүнсний бүрэн гүйцэд илэрхийлэл бөгөөд туйлын үнэн, харин ашиглагдаж буй хүмүүсийн ажилд хүний олон зүйл холилдсон байдаг ба Ариун Сүнсний шууд

илэрхийлэл биш, Түүний бүрэн гүйцэд илэрхийлэл бүр ч биш. Ариун Сүнсний ажил янз бүр байдаг бөгөөд ямар ч нөхцөлөөр хязгаарлагддаггүй. Ариун Сүнсний ажил нь өөр өөр хүмүүст ялгаатай байдаг; өөр өөр мөн чанарыг харуулдаг; мөн эрин үе, түүнчлэн улс орноор ялгаатай байдаг. Мэдээж Ариун Сүнс олон өөр аргаар, олон зарчмын дагуу ажилладаг хэдий ч тухайн ажлыг яаж хийдэг, эсвэл ямар хүмүүс дээр хийдэг нь хамаагүй, мөн чанар нь үргэлж өөр өөр байдаг; өөр өөр хүмүүс дээр хийдэг бүх ажил нь зарчимтай байдаг ба бүгд өөрсдийнхөө байны мөн чанарыг төлөөлж чаддаг. Учир нь Ариун Сүнсний ажил цар хүрээний хувьд нэлээд тодорхой, нэлээд нарийн хэмжүүртэй байдаг. Бурханы махбод болсон биед хийгддэг ажил нь хүмүүс дээр хийгддэг ажилтай адилгүй бөгөөд ажил хийгдэж буй хүмүүсийн хэв чанарын дагуу ажил ч бас ялгаатай байдаг. Бурханы махбод болсон биед хийгддэг ажил нь хүмүүс дээр хийгддэггүй бөгөөд энэ нь хүмүүс дээр хийгддэг ажлаас өөр. Товчхондоо, ажил яаж хийгддэг нь хамаагүй, өөр өөр объект дээр хийсэн ажил хэзээ ч адилхан байдаггүй бөгөөд Түүний ажилладаг зарчим нь өөр өөр хүмүүсийн байр байдал, уг чанарын дагуу ялгаатай байдаг. Ариун Сүнс төрөлх мөн чанарт нь үндэслэн өөр өөр хүмүүс дээр ажилладаг бөгөөд тэрхүү мөн чанараас нь хэтэрсэн шаардлагыг тэдэнд тавьдаггүй, төрөлх хэв чанараас нь давсан ажлыг ч тэдэн дээр хийдэггүй. Иймээс, хүн дээр хийдэг Ариун Сүнсний ажил нь тэрхүү ажлын байны мөн чанарыг харах боломжийг хүмүүст олгодог. Хүний төрөлх мөн чанар өөрчлөгддөггүй; төрөлхийн хэв чанар нь хязгаарлагдмал. Ариун Сүнс хүмүүсийн хэв чанарын хязгаарлалтад нийцүүлэн хүмүүсийг ашиглаж, эсвэл тэдэн дээр ажилладаг болохоор хүмүүс ашиг тусыг нь хүртэж болох юм. Ашиглагдаж буй хүмүүс дээр Ариун Сүнс ажиллах үед тэр хүмүүсийн бүхий л авьяас чадвар, төрөлхийн хэв чанар юу ч үлдэлгүйгээр гарч ирдэг. Тэдний төрөлхийн хэв чанар тухайн ажилд үйлчлэхэд хэрэглэгддэг. Тэрхүү ажлаар үр дүнд хүрэхийн тулд Тэрээр хүмүүсийн ашиглаж болох хэсгүүдийг ажилдаа ашигладаг гэж хэлж болох юм. Эсрэгээрээ, Бурханы махбод болсон биед хийгддэг ажил нь Сүнсний ажлыг шууд илэрхийлдэг бөгөөд хүний оюун санаа, бодол холилдоогүй; хүний авьяас билиг ч, хүний туршлага ч, эсвэл төрөлхийн нөхцөл байдал ч үүнд хүрч чадахгүй. Ариун Сүнсний тоймгүй олон ажил бүгд хүнд ач тусаа өгч, хүнийг босгон байгуулах учиртай. Гэхдээ зарим хүн төгс болгуулж чаддаг байхад бусад нь төгс болгуулах нөхцөл байдлыг эзэмшээгүй байдаг, өөрөөр хэлбэл, тэд төгс болгуулж чадахгүй, бараг аврагдаж чадахгүй ба хэдийгээр тэдэнд Ариун Сүнсний ажил байсан байж болох ч эцэст нь таягдан хаягддаг. Өөрөөр хэлбэл, Ариун Сүнсний ажил хүмүүсийг босгон байгуулахын төлөө байдаг хэдий ч Ариун Сүнсний ажилтай байсан бүх хүн бүрмөсөн төгс болгуулна гэж хэлж болохгүй, учир нь олон хүний эрэл хайгуулдаа дагадаг зам нь төгс болгуулах зам биш байдаг. Тэдэнд Ариун Сүнсний нэг талын ажил л байдаг, харин хүний субъектив хамтын ажиллагаа ч, зөв эрэл хайгуул ч байдаггүй. Тиймээс, энэ хүмүүс дээрх Ариун Сүнсний ажил нь төгс болгуулж байгаа хүмүүст үйлчилж эхэлдэг. Ариун Сүнсний ажлыг хүмүүс шууд

харж чадахгүй, өөрсдөө үүнд шууд хүрч ч чадахгүй. Харин ажиллах авьяас билигтэй хүмүүс л үүнийг илэрхийлж чаддаг ба хүмүүсийн илэрхийлдэг илэрхийллээр дамжуулан Ариун Сүнсний ажлыг дагалдагчдад өгдөг гэсэн үг юм.

Ариун Сүнсний ажил нь олон янзын хүмүүс, олон өөр нөхцөл байдлаар дамжин биелж, гүйцэлддэг. Бие махбодтой болсон Бурханы ажил хэдийгээр бүхэл бүтэн эриний ажлыг төлөөлж, бүхий л эрин дэх хүмүүсийн оролтыг төлөөлж чадах боловч хүмүүсийн нарийвчилсан оролт дээрх ажлыг бие махбодтой болсон Бурхан бус, харин Ариун Сүнсний ашигладаг хүмүүс хийх хэрэгтэй хэвээр юм. Тиймээс, Бурханы ажил буюу Бурханы Өөрийн үйлчлэл нь Бурханы махбод болсон биеийн ажил бөгөөд хүн оронд нь хийж чадахгүй. Ариун Сүнсний ажил нь өөр төрлийн олон хүнээр дамжин гүйцэлддэг; ганцхан хүн үүнийг бүрэн биелүүлж чадахгүй, ганцхан хүн бүрмөсөн илэрхийлж ч чадахгүй. Чуулгануудыг удирддаг хүмүүс ч бас Ариун Сүнсний ажлыг бүрэн төлөөлж чадахгүй; тэд зарим нэг удирдах ажлыг л хийж чадна. Тиймээс Ариун Сүнсний ажлыг, Бурханы Өөрийн ажил, ашиглагдаж буй хүмүүсийн ажил болон Ариун Сүнсний урсгалд байгаа бүх хүн дээрх ажил хэмээх гурван хэсэгт хувааж болно. Бурханы Өөрийн ажил бүхий л эринийг удирдан чиглүүлэх явдал; ашиглагддаг хүмүүсийн ажил нь Бурханыг ажлаа хийсний дараа илгээгдэх юм уу даалгавар хүлээн авснаар Бурханы бүх дагалдагчийг удирдан хөтлөх явдал бөгөөд тэд бол Бурханы ажилтай хамтран ажилладаг хүмүүс юм; урсгалд байгаа хүмүүс дээр Ариун Сүнсний хийдэг ажил нь Өөрийн бүх ажлыг хадгалах буюу Өөрийн бүхий л удирдлага болон гэрчлэлийг хадгалахын сацуу төгс болгуулж чадах хүмүүсийг төгс болгох явдал юм. Энэ гурван хэсэг нь хамтдаа Ариун Сүнсний бүрэн гүйцэд ажил боловч Бурханы Өөрийн ажилгүйгээр удирдлагын ажил тэр чигтээ зогсонги байдалд орно. Бурханы Өөрийн ажил бүх хүн төрөлхтний ажлыг хамардаг ба энэ нь бас бүхэл бүтэн эриний ажлыг төлөөлдөг. Өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн ажил нь Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн, чиг хандлага бүрийг төлөөлдөг, харин элч нарын ажил нь Бурханы Өөрийн ажлын дараа явагдаж, араас нь дагадаг ба эрин үеийг удирддаггүй, мөн бүхий л эрин дэх Ариун Сүнсний ажлын чиг хандлагыг ч төлөөлдөггүй. Тэд хүний хийх учиртай ажлыг л хийдэг бөгөөд энэ нь удирдлагын ажилтай ямар ч хамаагүй байдаг. Бурханы Өөрөө хийдэг ажил бол удирдлагын ажил доторх төсөл юм. Хүний ажил нь зөвхөн ашиглагдаж байгаа хүмүүсийн үүрэг бөгөөд удирдлагын ажилтай холбоогүй. Энэ хоёр хоёулаа Ариун Сүнсний ажил хэдий ч ялгамж чанар болон ажлын төлөөллийн ялгаанаас үүдэн Бурханы ажил болон хүний ажлын хооронд тодорхой, мөн чанарын ялгаа байдаг. Түүнчлэн, өөр өөр ялгамж чанартай байнууд дээр Ариун Сүнсний хийдэг ажлын хэмжээ ялгаатай байдаг. Эдгээр нь Ариун Сүнсний ажлын зарчим ба цар хүрээ юм.

Хүний ажил өөрийнх нь туршлага болон хүн чанарыг төлөөлдөг. Хүний хангадаг зүйл болон хийдэг ажил нь өөрийг нь төлөөлдөг. Хүний ойлголт, үндэслэл, логик болон баялаг төсөөлөл бүгд түүний ажилд агуулагддаг. Ялангуяа хүний туршлага

ажлыг нь төлөөлж чаддаг ба хүний туршлага ажлынх нь бүрэлдэхүүн хэсэг болдог. Хүний ажил туршлагыг нь илэрхийлж чадна. Зарим хүн сөргөөр туршлагажих үед тэдний нөхөрлөлийн ихэнх нь сөрөг элементүүдээс бүрдэнэ. Хэрэв хэсэг хугацаанд тэдний туршлага эерэг байж, тэд ялангуяа эерэг талын замыг эзэмшдэг бол нөхөрлөл нь тун зоригжуулам байдаг ба хүмүүс тэднээс эерэг хангалт олж авч чадна. Хэрэв ажилчин хэсэг хугацаанд идэвхгүй болбол нөхөрлөл нь үргэлж сөрөг элементүүдийг тээнэ. Ийм нөхөрлөл дарамттай бөгөөд түүний нөхөрлөлийн дараа бусад нь өөрийн эрхгүй сэтгэлээр унана. Дагалдагчдын байр байдал удирдагчийнхаас хамааран өөрчлөгддөг. Ажилчин дотроо ямархуу байна, түүнийгээ л илэрхийлдэг бөгөөд хүний байр байдлаас хамаарч Ариун Сүнсний ажил байнга өөрчлөгддөг. Тэрээр хүний туршлагын дагуу ажиллаж, хүнийг хүчилдэггүй боловч туршлагынх нь хэвийн явцын дагуу хүмүүст шаардлага тавьдаг. Өөрөөр хэлбэл, хүний нөхөрлөл Бурханы үгээс ялгаатай. Хүмүүсийн нөхөрлөдөг зүйл өөрсдийнх нь ойлголт болон туршлагыг дамжуулж, Бурханы ажилд үндэслэсэн ойлголт, туршлагыг нь илэрхийлдэг. Бурханыг ажиллаж, үг хэлсний дараа, юуг хэрэгжүүлж, юунд орох учиртайгаа олж мэдээд, дараа нь дагалдагчдад дамжуулах нь тэдний хариуцлага юм. Тиймээс хүний ажил өөрийнх нь оролт болон хэрэгжүүлэлтийг төлөөлдөг. Мэдээж ийм ажилд хүний сургамж, туршлага, эсвэл зарим нэг бодол холилдсон байдаг. Ариун Сүнс яаж ч ажилласан бай, хүн дээр, эсвэл бие махбодтой болсон Бурхан дээр ажиллах нь хамаагүй, ажилчид үргэлж юу болохоо илэрхийлж байдаг. Хэдийгээр Ариун Сүнс ажиллаж байгаа боловч тухайн ажил хүн төрөлхөөсөө юу болоход суурилдаг, учир нь Ариун Сүнс суурьгүйгээр ажилладаггүй. Өөрөөр хэлбэл, ажил оргүй хоосноос гарч ирдэггүй, харин үргэлж бодит орчин болон бодитой нөхцөл байдлын дагуу хийгддэг. Ийм маягаар л хүний зан чанар өөрчлөгдөж, хуучин үзэл, бодлууд нь өөрчлөгдөж болно. Хүний илэрхийлдэг зүйл нь түүний харж, туулдаг, мөн төсөөлж чадах зүйлс бөгөөд хоосон сургаал, эсвэл үзэл байлаа ч гэсэн, үүнд хүний сэтгэхүйгээр хүрч болохуйц байдаг. Хүний ажил ямар ч хэмжээтэй байсан бай, хүний туршлагын цар хүрээнээс давж чадахгүй, мөн хүний ойлгодог зүйл, эсвэл хүний төсөөлж, ухан ойлгож чадах зүйлийн цар хүрээнээс ч давж чадахгүй. Бурханы илэрхийлдэг зүйл нь Бурхан Өөрөө юу болох бөгөөд үүнд хүн хүршгүй—өөрөөр хэлбэл, үүнд хүний сэтгэхүйгээр хүрэх аргагүй. Тэрээр бүх хүн төрөлхтнийг удирдан чиглүүлэх ажлаа илэрхийлдэг бөгөөд энэ нь хүний туршлагын нарийн учиртай хамаагүй, харин Өөрийнх нь удирдлагатай холбоотой байдаг. Хүн өөрийн туршлагыг илэрхийлдэг бол Бурхан Өөрийн оршихуйг буюу Өөрийн төрөлх зан чанарыг илэрхийлдэг бөгөөд үүнд хүн хүршгүй. Хүний туршлага нь Бурханы оршихуйн илэрхийлэлд тулгуурлан олж авсан ойлголт болон мэдлэг юм. Ийм ойлголт болон мэдлэгийг хүний оршихуй гэдэг бөгөөд хүний төрөлх зан чанар, бодит хэв чанарт үндэслэн илэрхийлэгддэг—ийм учраас тэдгээрийг ч бас хүний оршихуй гэж нэрлэдэг. Хүн үзэж, туулдаг зүйлээ нөхөрлөж чаддаг. Өөрсдийн үзэж туулаагүй зүйлийг, эсвэл сэтгэхүйгээрээ хүрч

чадахгүй зүйлийг буюу өөрийнх нь дотор эс орших зүйлсийг хэн ч нөхөрлөж чадахгүй. Хэрвээ хүний илэрхийлдэг зүйл туршлагаас нь гардаггүй бол энэ нь түүний төсөөлөл юм уу хоосон номлол байдаг. Энгийнээр хэлбэл, түүний үгэнд ямар ч бодит байдал байдаггүй. Чи нийгмийн зүйлстэй огтхон ч харилцдаггүй бол нийгмийн төвөгтэй харилцааны талаар тодорхой нөхөрлөж чадахгүй. Хэрвээ чамд гэр бүл гэж байхгүй бол бусад хүмүүс гэр бүлийн асуудлын талаар ярилцах үед чи тэдний ярьж байгаа зүйлсийн ихэнхийг ойлгож чадахгүй. Иймээс хүний нөхөрлөдөг зүйл болон хийдэг ажил нь түүний дотоод оршихуйг төлөөлдөг. Хэрвээ хүн гэсгээлт, шүүлтийн талаарх ойлголтынхоо тухай нөхөрлөсөн боловч чамд энэ талаар ямар ч туршлага байхгүй бол чи түүний мэдлэгийг үгүйсгэж зүрхлэхгүй, тэр ч байтугай үүнд зуун хувь итгэлтэй байж ч зүрхлэхгүй. Яагаад гэвэл, түүний нөхөрлөл бол чиний хэзээ ч туулж байгаагүй, хэзээ ч мэдээгүй зүйл бөгөөд оюун санаа чинь үүнийг төсөөлж чадахгүй. Чи ирээдүйд шүүлт, гэсгээлт туулах замыг л түүний мэдлэгээс авч чадна. Гэхдээ энэ зам нь хоосон онолын мэдлэгийн зам л байж чадна; энэ нь чиний ойлголтыг орлож чадахгүй, туршлагыг чинь орлож бүр ч чадахгүй. Түүний хэлж байгаа зүйл нэлээд зөв юм гэж чи бодож магад боловч энэ нь олон талаар хэрэгжишгүй болохыг өөрийнхөө туршлагаар олж мэддэг. Магадгүй сонсож буй зарим зүйл чинь огт хэрэгжишгүй гэж санагддаг; тухайн үедээ чи энэ талаар үзэл өвөрлөдөг ба үүнийг хүлээн авдаг ч гэсэн маш дурамжхан хийдэг. Харин туршлагажих явцад чамд үзэл өгсөн мэдлэг чиний хэрэгжүүлэлтийн зам болдог ба хэрэгжүүлэх тусмаа чи сонссон үгийнхээ жинхэнэ үнэ цэн, утга учрыг улам бүр ойлгодог. Өөрийн гэсэн туршлагатай болсныхоо дараа чи туулсан зүйлээсээ олж авсан мэдлэгийн тухай ярьж чадна. Түүнчлэн, хэнийх нь мэдлэг жинхэнэ, бодитой, хэнийх нь мэдлэг хоосон сургаалд тулгуурласан, үнэ цэнгүй болохыг ялгаж чаддаг болно. Иймд чиний ярьдаг мэдлэг үнэнтэй нийцэж байгаа эсэх нь чамд бодит туршлага байгаа эсэхээс ихээхэн хамаардаг. Чиний туршлагад үнэн байгаа цагт мэдлэг чинь бодитой, үнэ цэнтэй байх болно. Туршлагаараа дамжуулан чи бас ялган таних чадвар, ойлголттой болж, мэдлэгээ гүнзгийрүүлж, биеэ хэрхэн авч явах тухай мэргэн ухаан, ерөнхий мэдлэгээ арвижуулж чадна. Үнэнийг эзэмшдэггүй хүмүүсийн илэрхийлсэн мэдлэг хэчнээн сүрлэг байлаа ч гэсэн, хоосон сургаал юм. Энэ төрлийн хүмүүс махан биеийн аливаа асуудалд маш ухаалаг байж болох боловч сүнслэг асуудлын тухайд ялган салгаж чаддаггүй. Учир нь ийм хүмүүст сүнслэг асуудалтай холбоотой туршлага огт байдаггүй билээ. Тэд бол сүнслэг асуудалд гэгээрээгүй, сүнслэг хэрэг явдлыг ойлгодоггүй хүмүүс юм. Чи ямар ч төрлийн мэдлэгийг илэрхийлдэг бай, энэ нь чиний оршихуй мөн л бол чиний хувийн туршлага, чиний бодит мэдлэг мөн. Зөвхөн хоосон сургаалын талаар ярьдаг хүмүүс буюу үнэнийг ч, бодит байдлыг ч эзэмшдэггүй хүмүүсийн ярьдаг зүйлийг ч бас тэдний оршихуй гэж хэлж болно, учир нь тэдний сургаал гүн эргэцүүллээс урган гарсан, оюун санааных нь гүн бодлогошролын үр дүн юм—гэхдээ энэ нь ердөө л хоосон сургаал, төсөөллөөс цаашгүй! Янз бүрийн хүмүүсийн туршлага өөрсдийнх

нь доторх зүйлсийг төлөөлдөг. Ямар ч сүнслэг туршлагагүй хүн үнэний мэдлэгийн талаар ярьж чадахгүй, янз бүрийн сүнслэг зүйлсийн талаарх зөв мэдлэгийг ч ярьж чадахгүй. Хүн дотор нь байгаа зүйлийг л илэрхийлдэг—энэ нь гарцаагүй. Хэрвээ хүн сүнслэг зүйлс болоод үнэний талаар мэдлэгтэй болохыг хүсвэл бодит туршлагатай байх ёстой. Хэрвээ чи хүний амьдралын ерөнхий мэдлэгийн талаар тодорхой ярьж чадахгүй бол сүнслэг зүйлсийн талаар бүр хэчнээн багыг ярьж чадах билээ? Чуулганыг удирддаг, хүмүүсийг амиар хангадаг, хүмүүст элч болдог хүмүүс бодит туршлагатай байх ёстой; тэд сүнслэг зүйлсийн талаар зөв ойлголттой, үнэний талаар зөв үнэлэлт, туршлагатай байх ёстой. Ийм хүмүүс л чуулганыг удирддаг ажилчид юм уу элчүүд байхад тохирно. Эс бөгөөс тэд зөвхөн хамгийн доод талын дагалдагч болж чадах ба удирдагч болж чадахгүй, хүмүүсийг амиар хангаж чаддаг элч байж бүр ч чадахгүй. Яагаад гэвэл, элч нарын чиг үүрэг нь яаран гүйж, тэмцэхийн төлөө бус, харин аминд үйлчлэх ажил хийж, зан чанараа өөрчлөхөд нь бусдыг удирдахын төлөө байдаг. Энэ чиг үүргийг гүйцэтгэдэг хүмүүс нь хүнд бэрх хариуцлага үүрэх даалгавар авдаг бөгөөд энэ нь хэн бүхний үүрч чадах зүйл биш юм. Ийм ажлыг амийн оршихуйтай буюу үнэний туршлагатай хүмүүс л хийж чадна. Хаяж орхидог, яаран гүйдэг, эсвэл өөрсдийгөө зарлагадахыг хүсдэг хэн бүхэн үүнийг хийж чадахгүй; үнэний туршлагагүй, засалт, шүүлт амсаагүй хүмүүс энэ төрлийн ажлыг хийж чадахгүй. Ямар ч туршлагагүй, бодит байдалгүй хүмүүс өөрсдөө иймэрхүү оршихуйгүй байдаг учраас бодит байдлыг тодорхой харж чаддаггүй. Иймээс энэ төрлийн хүн удирдах ажил хийж чадахгүйгээр үл барам, удаан хугацаанд үнэнгүй явбал таягдан хаягдана. Чиний илэрхийлдэг ойлголт амьдралдаа туулсан бэрхшээл, ямар асуудлаар гэсгээгдэж, шүүгдэж байсны чинь нотолгоо болдог. Шалгалтуудын хувьд ч энэ нь бас үнэн юм: Хүний цэвэршүүлэгдсэн зүйл, сул дорой байдаг зүйл нь түүний туулсан зүйл, замтай болсон зүйлс юм. Жишээ нь, хэрвээ хүний гэрлэлт бүтэлгүйтсэн бол тэр үргэлж “Бурханд баярлалаа, Бурханыг магтъя, би Бурханы зүрх сэтгэлийн хүслийг хангалуун байлгаж, нэг насны амьдралаа өргөн барьж, гэрлэлтээ тэр чигт нь Бурханы гарт даатгах ёстой. Би Бурханд бүхий л амьдралаараа дэнчин тавихад бэлэн байна” хэмээн нөхөрлөдөг. Хүний доторх бүх зүйл нь нөхөрлөлөөр дамжуулан, тэр юу болохыг харуулж чаддаг. Тухайн хүний ярианы хурд, чанга, эсвэл аяархан ярьдаг эсэх нь туршлагын асуудал биш учраас түүнд юу байгаа, тэр юу болохыг төлөөлж чадахгүй. Эдгээр зүйл нь тухайн хүний зан араншин болон уг чанар сайн уу, муу юу гэдгийг л хэлж чадах боловч түүнд туршлага байгаа эсэхтэй эн тэнцүү байж чадахгүй. Ярьж байх үедээ өөрийгөө илэрхийлэх чадвар, эсвэл ярианы чадвар болон хурд нь ердөө дадал зуршлаар бий болдог зүйл бөгөөд хүний туршлагыг орлож чадахгүй. Хувийн туршлагынхаа талаар ярих үедээ чи өөрийнхөө чухал гэж үздэг зүйлийг болон дотроо байгаа зүйлийг нөхөрлөдөг. Миний яриа Миний оршихуйг төлөөлдөг боловч Миний хэлдэг зүйлд хүн хүрэхийн аргагүй. Миний хэлдэг зүйл бол хүний туулдаг зүйл биш, мөн хүний харж чадах зүйл биш;

мөн хүний хүрч чадах зүйл биш, харин Би юу болох юм. Зарим хүн Миний нөхөрлөдөг зүйлийг үзэж туулсан зүйлс маань гэж л ойлгодог, гэхдээ энэ нь Ариун Сүнсний шууд илэрхийлэл гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Мэдээж Миний хэлдэг зүйлс Миний туулсан зүйл мөн. Би удирдлагын ажлыг зургаан мянган жил хийсэн. Би хүн төрөлхтөн бүтээгдэхээс эхлээд одоог хүртэлх бүхнийг туулсан; Би яаж энэ талаар ярьж чадахгүй байх юм бэ? Хүний уг чанарын тухайд гэвэл Би үүнийг тодорхой харсан; Би үүнийг аль эртнээс ажигласан. Тийм байхад Би яаж үүнийг тодорхой ярьж чадахгүй байх юм бэ? Хүний мөн чанарыг тодорхой харсан тул Би хүнийг гэсгээж, шүүхэд тохирно, учир нь бүх хүн Надаас үүссэн боловч Сатанаар завхруулагдсан. Мэдээж Би бас Өөрийн хийсэн ажлыг үнэлж дүгнэхэд тохирно. Хэдийгээр энэ ажлыг Миний махбод хийгээгүй ч, энэ нь Сүнсний шууд илэрхийлэл бөгөөд Надад юу байгаа, Би хэн болох юм. Тиймээс Би үүнийг илэрхийлж, Өөрийн хийх учиртай ажлыг хийхэд тохирно. Хүмүүсийн ярьдаг зүйл бол тэдний туулсан зүйлс юм. Энэ нь тэдний үзсэн зүйл, оюун ухаанаараа хүрч чадах зүйл бөгөөд мэдрэхүйгээрээ мэдэрч чадах зүйлс юм. Энэ л тэдний нөхөрлөж чадах зүйл билээ. Бурханы махбод болсон биеийн хэлсэн үг нь Сүнсний шууд илэрхийлэл бөгөөд Сүнсний хийсэн ажлыг илэрхийлдэг. Махбод нь үүнийг туулаагүй, хараагүй ч махбодын мөн чанар нь Сүнс учраас Түүний оршихуйг илэрхийлсээр байдаг ба Тэрээр Сүнсний ажлыг илэрхийлдэг. Махан бие үүнд хүрэх боломжгүй ч энэ нь Сүнсний аль хэдийн хийчихсэн ажил юм. Бие махбодтой болсныхоо дараа Тэрээр махбодын илэрхийллээр дамжуулан хүмүүст Бурханы оршихуйг мэдүүлж, Бурханы зан чанар болон Түүний хийсэн ажлыг харуулдаг. Хүний ажил нь юунд орох ёстой, юу ойлгох хэрэгтэйг хүмүүст илүү тодорхой болгож өгдөг; энэ нь хүмүүсийг үнэний тухай ойлголт, туршлага руу хөтөлдөг. Хүний ажил хүмүүст дэмжлэг үзүүлэхийн төлөө; Бурханы ажил нь хүн төрөлхтөнд шинэ зам, шинэ эринийг нээж, мөнх бус хүмүүсийн мэдэхгүй зүйлсийг хүмүүст илчилж, Бурханы зан чанарыг мэдэх боломж олгохын төлөө байдаг. Бурханы ажил бүх хүн төрөлхтнийг удирдан чиглүүлэхийн төлөө байдаг.

Ариун Сүнсний бүх ажил нь хүмүүст ашиг тус хүртээхийн төлөө хийгддэг; Энэ нь бүхэлдээ хүмүүсийг босгон байгуулахын төлөө юм; хүмүүст ашиг тусаа өгдөггүй ажил гэж нэгээхэн ч үгүй. Үнэн гүн гүнзгий ч бай, өнгөцхөн ч бай, мөн үнэнийг хүлээн авдаг хүмүүсийн хэв чанар ямар ч бай хамаагүй, Ариун Сүнсний хийдэг бүхэн хүмүүст ашиг тустай юм. Гэвч Ариун Сүнсний ажил шууд хийгдэх боломжгүй; харин Түүнтэй хамтран ажилладаг хүмүүсээр дамжин илэрхийлэгдэх ёстой. Тэгж байж л Ариун Сүнсний ажил үр дүнтэй болж чадна. Мэдээж Ариун Сүнсийг шууд ажиллах үед энэ нь огт хольцгүй байдаг; харин Ариун Сүнс хүнээр дамжуулан ажиллах үед тун их хольцтой болж, Ариун Сүнсний анхдагч ажил биш болдог. Ийм болохоор үнэн тодорхой хэмжээгээр өөрчлөгддөг. Дагалдагчид Ариун Сүнсний анхдагч санаа зорилгыг биш, харин Ариун Сүнсний ажил болон хүний туршлага, мэдлэгийн хослолыг хүлээн авдаг. Дагалдагчдын хүлээн авч байгаа Ариун Сүнсний ажлын нэг

хэсэг нь зөв байдаг, харин ажилчид өөр өөр учраас хүний хүлээн авсан мэдлэг, туршлага ялгаатай байдаг. Ариун Сүнсний гэгээрэл болон удирдамжтай ажилчид удирдамж болон гэгээрэлд үндэслэн улам туршлагажна. Эдгээр туршлага дотор хүний оюун ухаан, туршлага, түүнчлэн хүн чанарынх нь оршихуй холилддог ба үүний дараа тэд олж авах ёстой мэдлэг болон ойлголтоо олж авдаг. Энэ бол үнэнийг туулсны дараах хүний хэрэгжүүлэлтийн зам юм. Хүмүүсийн туршлага, туулдаг зүйлс өөр өөр учраас энэхүү хэрэгжүүлэлтийн зам нь үргэлж адилхан байдаггүй. Ийм маягаар, гэгээрлийг хүлээн авдаг хүмүүс өөр өөр учраас Ариун Сүнсний ижилхэн гэгээрлээс өөр өөр мэдлэг, хэрэгжүүлэлт урган гардаг. Зарим хүн хэрэгжүүлэх явцдаа жижиг алдаа гаргадаг бол зарим нь томоохон алдаа гаргадаг, харин зарим нь зөвхөн алдаа л гаргаж байдаг. Яагаад гэвэл, хүмүүсийн ойлгох чадвар ялгаатай, бас төрөлх хэв чанар нь ч ялгаатай байдаг. Зарим хүн номлол сонссоныхоо дараа нэг янзаар ойлгодог ба зарим нь үнэнийг сонссоныхоо дараа өөрөөр ойлгодог. Зарим хүн ялимгүй гаждаг, харин зарим нь үнэний жинхэнэ утга учрыг огтхон ч ойлгодоггүй. Тиймээс хүний ойлголт бусдыг хэрхэн удирдан хөтлөхийг нь тодорхойлдог; хүний ажил ердөө оршихуйнх нь илэрхийлэл учраас энэ нь яг үнэн юм. Үнэний талаар зөв ойлголттой хүнээр удирдуулсан хүмүүс ч бас үнэний тухай зөв ойлголттой байх болно. Ташаа ойлголттой хүмүүс байсан ч гэсэн, бүгдээрээ биш, цөөн хэд нь л алдаа мадагтай байна. Хэрвээ хүн үнэний талаар андуу ташаа ойлголттой бол түүнийг дагадаг хүмүүс ч бас эргэлзээгүй алдаа мадагтай байх бөгөөд энэ хүмүүс жинхэнэ утгаараа алдаа мадагтай байна. Дагалдагчдын үнэнийг ойлгох түвшин ажилчдаас ихээхэн хамаардаг. Мэдээж, Бурханаас ирдэг үнэн бол алдаа мадаггүй зөв, туйлын тодорхой байдаг. Харин ажилчид бүхэлдээ зөв байдаггүй, бас тэднийг бүрэн найдвартай гэж хэлж болохгүй. Хэрэв ажилчдад үнэнийг хэрэгжүүлэх маш бодитой арга зам байгаа бол дагалдагчид ч бас хэрэгжүүлэлтийн замтай байх болно. Харин ажилчдад үнэнийг хэрэгжүүлэх арга зам байхгүй, зөвхөн хоосон сургаал л байдаг бол дагалдагчид ямар ч бодит байдалгүй байна. Дагалдагчдын хэв чанар ба уг чанар нь төрөлхөөс заяагдсан бөгөөд ажилчидтай хамаагүй боловч дагалдагчдын үнэнийг ойлгож, Бурханыг мэдэх хэмжээ нь ажилчдаас хамаардаг (зарим хүний хувьд л ийм байдаг). Ажилчин ямар байна, удирдаж буй дагалдагчид нь ч тийм байна. Ажилчин өөрийн оршихуйг юу ч үлдээлгүй илэрхийлж байдаг. Өөрийг нь дагадаг хүмүүст тавьдаг шаардлагууд нь түүний хүрэхийг хүсэж буй, эсвэл хүрч чадах зүйлс юм. Ихэнх ажилчид өөрсдийн хийдэг зүйлд үндэслэн дагалдагчдадаа шаардлага тавьдаг ч дагалдагчдынх нь огт хүрч чадахгүй зүйл олон байдаг бөгөөд хүний хүрч чадахгүй зүйл оролтод нь саад болдог.

Засалт, харьцалт, шүүлт, гэсгээлт туулсан хүмүүсийн ажилд хамаагүй бага гажуудал байдаг бөгөөд тэдний ажлын илэрхийлэл хавьгүй нарийн зөв байдаг. Ажиллахдаа өөрийнхөө төрөлх байдалд найддаг хүмүүс нэлээд том алдаа гаргадаг. Төгс болгуулаагүй хүмүүсийн ажил өөрсдийнх нь төрөлх байдлыг

хэтэрхий их илэрхийлдэг бөгөөд энэ нь Ариун Сүнсний ажилд томоохон саад болдог. Хүний хэв чанар хэчнээн сайн байлаа ч, Бурханы даалгасан ажлыг хийхээсээ өмнө тэр бас засалт, харьцалт, шүүлт туулах ёстой. Хэрвээ ийм шүүлт туулаагүй бол тэд ажлаа хэчнээн сайн хийлээ ч гэсэн, үнэний зарчимтай нийцэхгүй ба үргэлж өөрсдийнх нь төрөлх байдал, хүний сайн сайхан л байдаг. Засалт, харьцалт, шүүлт туулсан хүмүүсийн ажил засалт, харьцалт, шүүлт туулаагүй хүмүүсийн ажлаас хавьгүй илүү нарийн зөв байдаг. Шүүлт туулаагүй хүмүүс, хүний оюуны чадамж, төрөлхийн авьяастай ихээхэн хутгалдсан хүний махан бие болон бодлыг л илэрхийлдэг. Энэ нь Бурханы ажлын тухай хүний нарийн зөв илэрхийлэл биш юм. Тийм хүмүүсийг дагадаг хүмүүс төрөлх хэв чанарынхаа дагуу тэдний өмнө ирдэг. Учир нь тэд Бурханы анхдагч санаа зорилготой бараг холбоогүй, үүнээс хэт хазайсан дэндүү их ойлголт, туршлагыг илэрхийлдэг учраас ийм төрлийн хүний ажил нь хүмүүсийг Бурханы өмнө биш, өөрийнх нь өмнө л аваачиж чадна. Иймээс Бурханы шүүлт, гэсгээлтийг туулаагүй хүмүүс Бурханы даалгасан ажлыг гүйцэтгэхэд тэнцдэггүй. Шалгуурт нийцсэн ажилчны ажил хүмүүсийг зөв замд аваачиж, үнэнд улам их орох боломж олгож чаддаг. Түүний ажил хүмүүсийг Бурханы өмнө авчирч чаддаг. Түүнчлэн, түүний хийдэг ажил нь хүнээс хүнд ялгаатай байж болдог, дүрэмд баригддаггүй бөгөөд хүмүүст чөлөөлөлт, эрх чөлөө, амиа аажмаар өсгөх, үнэнд илүү гүн орох чадавх олгодог. Харин шалгуурт нийцээгүй ажилчны ажил хамаагүй тааруухан байдаг. Бас ажил нь мунхаг байдаг. Тэрээр хүмүүсийг дүрэм рүү л аваачиж чаддаг ба хүмүүсээс шаарддаг зүйл нь хүнээс хүнд ялгаатай байдаггүй; тэрээр хүмүүсийн бодит хэрэгцээний дагуу ажилладаггүй. Ийм төрлийн ажилд, хэтэрхий олон дүрэм, хоосон сургаал байдаг бөгөөд хүмүүсийг бодит байдал руу ч, амийн өсөлтийн хэвийн хэрэгжүүлэлт рүү ч аваачиж чаддаггүй. Энэ нь хүмүүсээр үнэ цэнгүй цөөн хэдэн дүрэм журмыг баримтлуулдаг. Ийм удирдамж нь хүмүүсийг буруу замаар оруулж л чадна. Тэр чамайг өөртэйгөө адилхан болгож, өөрт нь юу байгаа, өөрөө юу болох руугаа л аваачиж чадна. Дагалдагчдын хувьд удирдагчид нь шалгуур хангадаг эсэхийг ялган таних гол түлхүүр бол тэдний удирдан чиглүүлдэг зам, ажлын үр дүнг харах, мөн дагалдагчид нь үнэнтэй нийцэлтэй зарчмыг хүлээн авдаг эсэх, өөрчлөгдөхөд нь тохирсон хэрэгжүүлэлтийн замыг хүлээн авдаг эсэхийг харах хэрэгтэй. Чи өөр өөр хүмүүсийн янз бүрийн ажлыг хооронд нь ялгах хэрэгтэй; чи мунхаг дагалдагч байх ёсгүй. Энэ нь хүмүүсийн оролтын хэрэг явдалд нөлөөлдөг. Хэрвээ чи аль хүний удирдлагад зам байгаа, алинд нь байхгүй болохыг ялган салгаж чадахгүй бол амархан мэхлэгдэнэ. Энэ бүгд чиний өөрийн амьтай шууд хамаатай. Төгс болгуулаагүй хүмүүсийн ажилд төрөлх байдал дэндүү их байдаг; үүнд хүний хүсэл дэндүү их холилдсон байдаг. Тэдний оршихуй нь төрөлх байдал, тэдэнд төрөлхөөс заяагдсан зүйл юм. Энэ нь харьцалт туулсны дараах амь, эсвэл өөрчлөгдсөний дараах бодит байдал биш. Ийм хүн яаж амийг эрэлхийлж буй хүмүүст дэмжлэг үзүүлж чадах юм бэ? Хүнд анхнаасаа байдаг амь нь түүний төрөлх оюуны чадамж,

эсвэл авьяас билиг юм. Ийм төрлийн оюуны чадамж, авьяас билиг нь хүнд тавих Бурханы нарийн шаардлагаас нэлээд зөрүүтэй байдаг. Хэрвээ хүн төгс болгуулаагүй, завхарсан зан чанар нь засалт, харьцалт туулаагүй бол түүний илэрхийлдэг зүйлс болон үнэний хооронд томоохон зай гарна; түүний илэрхийлдэг зүйл өөрийнх нь төсөөлөл, өрөөсгөл туршлага гэх мэт тодорхойгүй зүйлстэй холилдоно. Түүнчлэн тэр яаж ч ажилладаг бай, ерөнхий зорилго болон бүх хүний оролтод тохирох үнэн огт байхгүй мэт хүмүүст санагддаг. Хүмүүст тавьдаг шаардлагуудын ихэнх нь тэдний чадвараас давдаг бөгөөд чадахгүй зүйлийг нь хийлгэхээр тэднээс шаардаж буй мэт байдаг. Энэ бол хүний хүслийн ажил юм. Хүний завхарсан зан чанар, бодол болон үзэл нь түүний бүх биеэр нэвчсэн байдаг. Хүн үнэнийг хэрэгжүүлэх зөн билигтэй төрөөгүй, мөн үнэнийг шууд ойлгох зөн билиг ч түүнд байдаггүй. Хүний завхарсан зан чанартай зэрэгцээд ийм төрөлх байдалтай хүн ажиллах аваас саад учруулахгүй гэж үү? Харин төгс болгуулсан хүнд хүмүүсийн ойлгох ёстой үнэний туршлага болон тэдний завхарсан зан чанарын тухай мэдлэг байдаг, ингэснээр түүний ажил дахь тодорхойгүй, бодитой бус зүйлс аажмаар багасаж, хүний хольц нь цөөрч, ажил болон үйлчлэл нь Бурханы шаарддаг стандартад улам бүр ойртдог. Тиймээс, түүний ажил үнэн-бодит байдалд орсон бөгөөд бас бодитой болсон. Хүний оюун ухаанд орших бодлууд ялангуяа Ариун Сүнсний ажилд саад учруулдаг. Хүнд баялаг төсөөлөл, үндэслэлтэй логик болон аливаа хэрэг явдлыг зохицуулах урт хугацааны туршлага бий. Хэрвээ хүний эдгээр талыг засаж, зөвтгөхгүй бол бүгд ажилд садаа болдог. Тиймээс хүний ажил, ялангуяа төгс болгуулаагүй хүмүүсийн ажил хамгийн нарийн зөв түвшинд хүрч чадахгүй.

Хүний ажилд цар хүрээ, хязгаарлалт гэж бий. Нэг хүн тодорхой үе шатны ажлыг л хийнэ үү гэхээс бүхий л эрин үеийн ажлыг хийж чадахгүй—эс бөгөөс тэрээр хүмүүсийг нэг төрлийн дүрэм журам руу хөтлөх байлаа. Хүний ажил зөвхөн тодорхой цаг хугацаа, үе шатанд л хэрэглэгдэж болно. Учир нь хүний туршлагад цар хүрээ байдаг. Хүний ажлыг Бурханы ажилтай харьцуулж болохгүй. Хүний хэрэгжүүлэлтийн зам болон үнэний тухай мэдлэг нь бүгд тодорхой цар хүрээнд тохиромжтой. Иймд хүний алхдаг замыг бүхэлдээ Ариун Сүнсний хүсэл гэж хэлж болохгүй, учир нь хүнийг Ариун Сүнс л гэгээрүүлж чадах бөгөөд Ариун Сүнс түүнийг бүрэн дүүргэж чадахгүй. Хүний туулж болох зүйлс бүгд хэвийн хүн чанарын цар хүрээн дотор байдаг ба хэвийн хүний оюун ухаан дахь бодлын хүрээнээс хальж чадахгүй. Үнэн-бодит байдлыг амьдран харуулж чаддаг бүх хүн энэ цар хүрээн дотор туршлагаждаг. Тэд үнэнийг туулах үед, энэ нь үргэлж Ариун Сүнсний гэгээрүүлсэн хэвийн хүний амьдралын туршлага байдаг ба хэвийн хүний амьдралаас гаждаг туршлагажих зам биш юм. Тэд хүний амьдралаар амьдарсан суурин дээрээ Ариун Сүнсний гэгээрүүлсэн үнэнийг туулдаг. Түүнчлэн, энэ үнэн нь хүнээс хүнд янз бүр байдаг бөгөөд гүн гүнзгий байдал нь тухайн хүний байр байдлаас хамаардаг. Тэдний алхдаг зам нь үнэнийг эрэлхийлдэг хэвийн хүний амьдрал, мөн Ариун Сүнсний гэгээрүүлсэн хэвийн хүний алхдаг зам гэж хэлж болно. Тэдний

алхдаг замыг Ариун Сүнсний алхдаг зам гэж хэлж болохгүй. Эрэлхийлдэг хүмүүс нь адилгүй учраас хэвийн хүний туршлагад Ариун Сүнсний ажил ч бас адилгүй байдаг. Түүнчлэн, хүмүүсийн туулдаг орчин болон туршлагын цар хүрээ адилгүй байдаг учраас, мөн оюун ухаан, бодол нь холилдсон байдаг учраас тэдний туршлага янз бүрийн түвшинд хольцтой байдаг. Хүн бүр тус тусын өөр нөхцөл байдлынхаа дагуу үнэнийг ойлгодог. Үнэний жинхэнэ утга учрын талаарх тэдний ойлголт бүрэн бус байдаг ба ердөө л ганц юм уу цөөн хэдэн тал байдаг. Хүний туулдаг үнэний цар хүрээ нь хүн бүрийн нөхцөл байдалд тулгуурлан хүнээс хүнд үргэлж ялгаатай байдаг. Ийм маягаар, нэг үнэний талаар өөр өөр хүмүүсийн илэрхийлсэн мэдлэг адилхан байдаггүй. Өөрөөр хэлбэл, хүний туршлага үргэлж хязгаартай байж, Ариун Сүнсний хүслийг бүрэн төлөөлж чаддаггүй бөгөөд хүний илэрхийлж буй зүйл Бурханы хүсэлтэй маш ойр нийцэж байсан ч гэсэн, мөн хүний туршлага Ариун Сүнсний явуулдаг төгс болгох ажилтай тун ойр байсан ч гэсэн хүний ажлыг Бурханы ажил гэж үзэж болохгүй. Хүн зөвхөн Бурханы зарц байж, даалгасан ажлыг нь хийж л чадна. Хүн Ариун Сүнсний гэгээрлээс олж авсан мэдлэг болон хувийн туршлагаараа олж авсан үнэнийг илэрхийлж л чадна. Хүн Ариун Сүнсний гарц байхад тэнцдэггүй, мөн болзлыг нь хангадаггүй. Өөрийнх нь ажил бол Бурханы ажил гэж хэлэх эрхгүй. Хүнд хүний ажиллах зарчим гэж байдаг, бүх хүн янз бүрийн туршлага, олон янзын нөхцөл байдалтай байдаг. Хүний ажилд Ариун Сүнсний гэгээрэл дор олж авсан бүх туршлага нь багтдаг. Эдгээр туршлага хүний оршихуйг л төлөөлж чадна уу гэхээс Бурханы оршихуй, Ариун Сүнсний хүслийг төлөөлдөггүй. Тиймээс хүний алхдаг замыг Ариун Сүнсний алхдаг зам гэж хэлж болохгүй, учир нь хүний ажил Бурханы ажлыг төлөөлж чаддаггүй бөгөөд хүний ажил болон туршлага нь Ариун Сүнсний бүрэн гүйцэд хүсэл биш юм. Хүний ажил дүрэмд баригдахдаа амархан бөгөөд ажлынх нь арга барил хязгаарлагдмал хүрээнд хялбархан баригдаж, хүмүүсийг чөлөөтэй зам руу хөтөлж чаддаггүй. Ихэнх дагалдагч хязгаарлагдмал хүрээн дотор амьдардаг ба туршлагажих зам нь ч хязгаарлагдмал цар хүрээтэй байдаг. Хүний туршлага үргэлж хязгаарлагдмал байдаг; ажлын арга барил нь ч бас хэдхэн төрлөөр хязгаарлагддаг ба Ариун Сүнсний ажил юм уу Бурханы Өөрийн ажилтай харьцуулж болохгүй. Учир нь хүний туршлага эцсийн эцэст хязгаарлагдмал билээ. Харин Бурхан ажлаа хийхдээ дүрэм журамд баригддаггүй; үүнийг яаж ч хийлээ гэсэн ганцхан арга барилаар хязгаарлагддаггүй. Бурханы ажилд ямар ч дүрэм гэж байдаггүй—Түүний бүх ажил хязгаарлалтгүй, чөлөөтэй байдаг. Хүн Түүнийг дагахдаа хэчнээн ч их хугацаа зарцууллаа гэсэн Бурханы ажиллах арга замыг захирдаг ямар ч хуулийг нэгтгэн дүгнэж чаддаггүй. Түүний ажил зарчимтай хэдий ч үргэлж шинэ арга замаар хийгдэн, ямагт шинэ өрнөлтэй байдаг, үүнд хүн хүрэх аргагүй. Ганцхан цаг үед Бурхан хэд хэдэн өөр төрлийн ажил, хүмүүсийг удирдах өөр өөр арга замтай байж, хүмүүсийг үргэлж шинэ оролт, шинэ өөрчлөлттэй байлгаж болно. Тэр үргэлж шинэ арга замаар ажиллаж байгаа учраас Түүний ажлын хуулийг чи ялган таньж

чадахгүй бөгөөд тиймээс л Бурханыг дагалдагчид дүрэмд баригддаггүй. Бурханы Өөрийн ажил үргэлж хүмүүсийн үзлээс зайлсхийж, үзлийг нь сөрдөг. Чин сэтгэлээсээ Түүнийг дагаж, эрэлхийлдэг хүмүүс л зан чанараа өөрчилж, ямар нэг дүрэм журамд баригдах юм уу шашны үзэлд авталгүйгээр чөлөөтэй амьдарч чаддаг. Хүний ажил өөрийнхөө хувийн туршлага, хүрч чадах зүйлд үндэслэн хүмүүст шаардлага тавьдаг. Эдгээр шаардлагын стандарт нь тодорхой цар хүрээн дотор хязгаарлагдаж, хэрэгжүүлэх арга барил нь ч бас маш хязгаарлагдмал байдаг. Тиймээс дагалдагчид өөрийн мэдэлгүй энэ хязгаарлагдмал цар хүрээн дотор амьдардаг; цаг хугацаа өнгөрөхийн хэрээр эдгээр зүйл дүрэм журам, зан үйл болдог. Хэрвээ Бурханаар биечлэн төгс болгуулж, шүүгдээгүй хүн нэг цаг үеийн ажлыг удирдвал дагалдагчид нь бүгд шашны хуучинсаг үзэлтнүүд болж, Бурханыг эсэргүүцэхдээ мэргэжилтэн болдог. Тиймээс, хэрвээ хүн шаардлага хангасан удирдагч мөн юм бол шүүлт туулж, төгс болголтыг хүлээн авсан байх ёстой. Шүүлт туулаагүй хүмүүс хэдий Ариун Сүнсний ажилтай байж болох ч гэсэн тодорхойгүй, бодит бус зүйлсийг л илэрхийлдэг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд хүмүүсийг тодорхойгүй, ер бусын дүрэм журам руу хөтөлнө. Бурханы гүйцэтгэдэг ажил хүний махан биетэй нийцдэггүй. Энэ нь хүний бодолтой нийцдэггүй, харин хүний үзлийг сөрдөг; мөн шашны тодорхойгүй өнгө аясаар гутаагддаггүй. Бурханы ажлын үр дүнд Түүгээр төгс болгуулаагүй хэн нэгэн хүрч чадахгүй, мөн үүнд хүний сэтгэхүй хүршгүй юм.

Хүн оюун санаандаа байгаа ажлыг маш амархан гүйцэтгэдэг. Жишээлбэл, шашны ертөнцийн пастор, удирдагчид авьяас билиг, байр сууриндаа тулгуурлан ажлаа хийдэг. Удаан хугацаанд тэднийг дагасан хүмүүст тэдний авьяас билиг халдварлаж, оршихуйн зарим нь нөлөөлнө. Тэд хүмүүсийн авьяас билиг, ур чадвар, мэдлэгт анхаарч, мөн ер бусын зүйл, бодит бус гүн гүнзгий олон сургаалд (мэдээж, эдгээр гүн гүнзгий сургаалд хүрэхийн аргагүй) анхаарал хандуулдаг. Тэд хүмүүсийн зан чанарын өөрчлөлтөд анхаарлаа төвлөрүүлдэггүй, харин хүмүүсийг номлох, ажиллахад сургаж, тэдний мэдлэг болон элбэг арвин шашны сургаалыг сайжруулахад анхаардаг. Хүмүүсийн зан чанар хэр их өөрчлөгдсөнийг, хүмүүс үнэнийг хэр их ойлгож байгааг тэд анхаардаггүй. Тэд хүмүүсийн хэвийн болон хэвийн бус байдлын талаар мэдэх гэж оролдох нь байтугай, мөн чанарынх нь талаар ч хайхардаггүй. Хүмүүсийн үзлийг сөрдөггүй, үзлийг нь ч илчилдэггүй, дутагдал, завхралынх нь төлөө хүмүүсийг засаж бүр ч чаддаггүй. Тэднийг дагадаг ихэнх хүн авьяас билгээрээ үйлчилдэг ба илэрхийлдэг бүхэн нь бодит байдалтай хамааралгүй, хүмүүст амь өгч огт чадахгүй шашны үзэл, теологийн онол байдаг. Үнэндээ тэдний ажлын мөн чанар нь авьяасыг хөгжүүлж, юу ч үгүй хүнийг хөгжүүлээд, хожим нь ажиллаж, удирдахаар явах шашны сургуулийн авьяаслаг төгсөгч болгох явдал юм. Бурханы зургаан мянган жилийн ажлаас чи ямар нэг хууль дүрмийг олж мэдэж чадах уу? Хүний хийдэг ажилд маш олон дүрэм, хязгаарлалт байдаг ба хүний ууриг тархи хэтэрхий онолдох дуртай. Тиймээс хүний

илэрхийлдэг зүйл бол өөрийнх нь туршлагын цар хүрээн доторх ухаарал, мэдлэг юм. Хүн үүнээс өөр зүйлийг илэрхийлж чадахгүй. Хүний туршлага болон мэдлэг нь түүний төрөлхийн авьяас билгээс, эсвэл зөн билгээс гардаггүй; харин Бурханы удирдамж, шууд хариулгаас гарч ирдэг. Хүн зөвхөн энэ хариулгыг хүлээн авах чадвартай болохоос биш, бурханлаг чанар юу болохыг шууд илэрхийлж чаддаг чадвар байхгүй. Хүн өөрөө эх сурвалж байж чадахгүй; зөвхөн эх сурвалжаас ус хүлээж авдаг сав л байж чадна; энэ бол хүний зөн билиг, хүн болгонд байх ёстой чадвар юм. Хэрвээ хүн Бурханы үгийг хүлээн авах чадвараа алдаж, хүний зөн билгээ гээвэл хамгийн эрхэм нандин зүйлээ ч бас алдаж, бүтээгдсэн хүний үүргийг алддаг. Хэрвээ хүнд Бурханы үг юм уу ажлын тухай мэдлэг, туршлага байхгүй бол тэр хүн өөрийн үүргийг буюу бүтээл болохынхоо хувьд гүйцэтгэх ёстой үүргээ алдаж, бүтээлийн эрхэм чанараа алддаг. Махбодоор юм уу Сүнсээр шууд илэрхийлэгдсэн эсэх нь хамаагүй бурханлаг чанар юу болохыг илэрхийлэх нь Бурханы зөн билиг юм; энэ нь Бурханы үйлчлэл билээ. Хүн өөрийн туршлага, эсвэл мэдлэгийг Бурханы ажлын үеэр юм уу дараа нь илэрхийлдэг (өөрөөр хэлбэл, тэр юу болохоо илэрхийлдэг); энэ бол хүний зөн билиг, үүрэг бөгөөд хүний биелүүлэх ёстой зүйл юм. Хэдийгээр хүний илэрхийлэл Бурханы илэрхийлдэг зүйлээс хамаагүй дутуу боловч хүний илэрхийлэл олон дүрэм журамд баригддаг, хүн биелүүлэх ёстой үүргээ биелүүлж, хийх ёстой зүйлээ хийх учиртай. Хүн үүргээ биелүүлэхийн тулд боломжтой бүхнийг хийх ёстой бөгөөд өчүүхэн төдий ч биеэ нөөсөн явдал байх ёсгүй.

Олон жил ажилласны дараа хүн тэр хугацааныхаа ажлын туршлага, хуримтлуулсан мэргэн ухаан, дүрэм журмыг нэгтгэн дүгнэнэ. Удаан хугацааны турш ажилласан хүн Ариун Сүнсний ажлын хөгжил хөдөлгөөнийг хэрхэн мэдрэхээ мэддэг; Ариун Сүнс хэзээ ажиллаж байгаа, хэзээ ажиллахгүй байгааг мэддэг; ачаа үүрч байх үедээ хэрхэн нөхөрлөхөө мэддэг; Ариун Сүнсний ажлын хэвийн байдал болон хүмүүсийн амийн өсөлтийн хэвийн байдлыг мэддэг. Энэ бол олон жил ажилласан, Ариун Сүнсний ажлыг мэддэг хүн юм. Олон жил ажилласан хүмүүс эргэлзээгүйгээр, тайван ярьдаг; хэлэх юмгүй байхдаа ч гэсэн тайван дөлгөөн байдаг. Дотроо тэд Ариун Сүнсний ажлыг эрж хайн залбирсаар байж чаддаг. Тэд ажилдаа туршлагажсан байдаг. Удаан хугацаанд ажилласан, ихээхэн туршлагатай, олон хичээл сурсан хүмүүсийн дотор Ариун Сүнсний ажилд саад учруулах зүйл олон байдаг; энэ бол удаан хугацааны ажлынх нь дутагдалтай тал юм. Дөнгөж ажиллаж эхэлсэн хүн хүний сургамж, туршлагаар дутмаг, ялангуяа Ариун Сүнс хэрхэн ажилладаг талаар мэдэх ч үгүй байдаг. Гэхдээ ажлын явцад тэрээр Ариун Сүнс хэрхэн ажилладгийг аажмаар мэдэрч сурдаг ба Ариун Сүнсний ажлыг олж авахын тулд юу хийх, бусдын яг сул талыг цохихын тулд юу хийх гэх мэт ажиллаж байгаа хүмүүсийн эзэмших шаардлагатай ердийн мэдлэгийг мэдэж авдаг. Цаг хугацаа өнгөрөх тусам тэрээр ажиллах тухай тийм мэргэн ухаан, ерөнхий мэдлэгийг арван хуруу шигээ мэддэг болж, ажиллах үедээ тэдгээрийг хялбархан ашиглаж байгаа

мэт санагддаг. Гэвч, Ариун Сүнс ажиллах байдлаа өөрчлөх үед тэр, хуучин ажлын мэдлэг болон хуучин ажлын дүрэмтэйгээ л зууралддаг бөгөөд ажлын шинэ хөдөлгөөний тухай тун бага мэддэг. Олон жилийн ажил, Ариун Сүнсний оролцоо болон удирдамжаар дүүрэн байсан нь түүнд ажиллах сургамж, туршлагыг улам их өгдөг. Ийм зүйлс нь түүнийг бардамнал бус, харин өөртөө итгэх итгэлээр дүүргэдэг. Өөрөөр хэлбэл, тэрээр өөрийнхөө ажилд сэтгэл хангалуун байж, Ариун Сүнсний ажлаас олж авсан ерөнхий мэдлэгтээ ханамжтай байдаг. Ялангуяа, бусад хүмүүсийн олж аваагүй, ухаараагүй зүйлс нь түүнд өөртөө илүү их итгэх итгэлийг өгдөг; түүний доторх Ариун Сүнсний ажил хэзээ ч алга болохгүй, харин бусад нь ингэж онцгойлуулах эрхгүй юм шиг санагддаг. Олон жилийн турш ажилласан, ашиглалтын үнэ цэн ихтэй түүн шиг төрлийн хүмүүс л үүнийг эдлэхэд тохирно. Эдгээр зүйл Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн авахад нь асар их саад болдог. Тэрээр шинэ ажил хүлээн авч чадах байсан ч гэсэн ганцхан шөнийн дотор хийж чадахгүй. Үүнийг хүлээн авахын өмнө хэд хэдэн нугачааг давах нь гарцаагүй. Түүний хуучин үзэлтэй харьцаж, хуучин зан чанарыг нь шүүсний дараа л энэ нөхцөл байдал аажмаар өөрчлөгдөж болно. Эдгээр алхмыг туулахгүйгээр тэр бууж өгч, хуучин үзэлтэй нь үл зохилдох шинэ сургаал болон ажлыг хялбархан хүлээн авахгүй. Энэ бол хүний доторх харьцахад хамгийн хэцүү зүйл бөгөөд үүнийг өөрчлөх нь амаргүй. Хэрвээ, ажилчин болохын хувьд тэр Ариун Сүнсний ажлыг ойлгох чадвартай, хөгжил хөдөлгөөнийг нь дүгнэх чадвартай, түүнчлэн ажлын туршлагадаа хязгаарлагдахгүй байж, хуучин ажлын үр дүнд шинэ ажлыг хүлээн авч чаддаг бол ухаалаг агаад уг ажилд тэнцсэн ажилчин юм. Хүмүүс ихэвчлэн ийм байдаг: Тэд ажлын туршлагаа дүгнэж чадалгүй хэдэн жил ажилладаг, эсвэл ажилтай холбоотой туршлага, мэргэн ухаанаа нэгтгэн дүгнэсний дараа шинэ ажлыг хүлээн авахад нь саад тулгараад, хуучин болон шинэ ажлыг зөвөөр ойлгож, тэдгээрт зөв зүйтэй хандаж чаддаггүй. Хүмүүсийн учрыг олоход үнэхээр хэцүү! Та нарын ихэнх нь ийм байдаг. Олон жил Ариун Сүнсний ажлыг туулсан хүмүүсийн хувьд шинэ ажлыг хүлээн авахад хэцүү байдаг бөгөөд хойш тавьж чадахгүй үзлээр үргэлж дүүрэн байдаг байхад харин дөнгөж ажиллаж эхэлсэн хүмүүст ажлын тухай ерөнхий мэдлэг дутмаг байдаг ба хамгийн энгийн хэрэг явдлуудыг ч яаж шийдэхээ мэддэггүй. Хүмүүс та бүхэн үнэхээр хэцүү! Жаахан зиндаа дээгүүр болмогцоо биеэ тоож, ихэрхүү зан гаргаж, хэзээ төрснөө мартдаг. Тэд залуусыг үргэлж дорд үздэг, гэсэн атлаа өөрсдөө шинэ ажлыг хүлээн авч чаддаггүй, олон жилийн турш цуглуулж, хадгалсан хуучин үзлээсээ салж чаддаггүй. Мэдлэггүй тэр залуус Ариун Сүнсний шинэ ажлын багахныг хүлээн авах чадвартай, нэлээд урам зоригтой байдаг ч асуудал тулгарах үед үргэлж будилж, яахаа мэддэггүй. Тэд урам зоригтой байдаг ч мэдлэггүй. Тэд Ариун Сүнсний ажлын талаар өчүүхэн мэдлэгтэй байхын дээр түүнийгээ амьдралдаа ашиглаж чаддаггүй; энэ нь зүгээр л тэр чигтээ хэрэггүй хоосон сургаал юм. Та нар шиг хүмүүс хэтэрхий олон байдаг; хэчнээн нь энэ ажилд тохирох бол? Хэд нь Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг дуулгавартай дагаж,

Бурханы хүсэлтэй нийцэж чадах бол? Одоог хүртэл дагалдагч байсаар ирсэн та бүхэн маш дуулгавартай байсан мэт санагдаж байгаа ч үнэндээ та нар өөрсдийн үзлийг орхиогүй, одоог хүртэл Библиэс эрж хайж, тодорхойгүй байдалд итгэж, үзэлдээ хэрэн хэсүүчилдэг. Өнөөдрийн бодит ажлыг анхааралтай судалж, гүн рүү нь ордог хэн ч үгүй. Та нар хуучин үзлээрээ өнөөдрийн замыг хүлээн авч байгаа. Ийм итгэл үнэмшлээс та нар юу олж авч чадах юм бэ? Та нарын дотор илчлэн харуулаагүй маш олон үзэл нуугддаг гэж хэлж болох ба та нар тэдгээрийг нуун далдалж, амархан илчлэхгүйн тулд дээд зэргийн хичээл чармайлт гаргаж байгаа. Та нар шинэ ажлыг чин сэтгэлээсээ хүлээн авдаггүй, хуучин үзлээсээ салахаар төлөвлөдөггүй; та нарт хэтэрхий олон амьдралын гүн ухаан байдаг ба тэдгээр нь нэлээд их. Та нар хуучин үзлээ хаядаггүй, шинэ ажилтай дурамжхан харьцдаг. Та нарын зүрх сэтгэл хэтэрхий зусар бөгөөд шинэ ажлын алхмуудыг үнэн сэтгэлээсээ авч үздэггүй. Та нар шиг ийм гологдлууд сайн мэдээ түгээх ажлыг хийж чадах уу? Үүнийг бүхий л орчлон ертөнц даяар түгээх ажлыг хийж чадна гэж үү? Та нарын энэ хэрэгжүүлэлт зан чанараа өөрчилж, Бурханыг мэдэхэд чинь саад учруулж байна. Хэрвээ та нар ийнхүү ургэлжлүүлбэл таягдан хаягдана.

Та нар Бурханы ажлыг хүний ажлаас яаж ялгахаа мэддэг байх ёстой. Хүний ажлаас чи юу харж болох вэ? Хүний ажилд хүний туршлагын маш олон элемент байдаг; хүн өөрийнхөө юу болохыг илэрхийлдэг. Бурханы Өөрийн ажил ч бас Тэр юу болохыг илэрхийлдэг боловч Түүний оршихуй нь хүнийхээс өөр юм. Хүний оршихуй нь хүний туршлага болон амьдралыг (амьдралдаа туулж, тулгардаг зүйлс, хүнд байдаг амьдралын гүн ухааныг) төлөөлдөг ба өөр өөр орчинд амьдарч байгаа хүмүүс өөр өөр оршихуйг илэрхийлдэг. Нийгмийн туршлагатай эсэх, гэр бүлдээ яг хэрхэн амьдарч, туршлагаждаг вэ гэдгийг чинь чиний илэрхийлдэг зүйлээс харж болдог бол бие махбодтой болсон Бурханы ажлаас Түүнд нийгмийн туршлага байгаа эсэхийг харах аргагүй. Бурхан хүний мөн чанарыг сайн мэддэг бөгөөд бүх төрлийн хүмүүст хамаатай төрөл бүрийн хэрэгжүүлэлтийг илчилж чадна. Тэрээр хүний ялзарсан зан чанар, тэрслүү үйлдлийг бүр ч сайн илчилж чаддаг. Тэрээр ертөнцийн хүмүүс дунд амьдардаггүй боловч эгэл хүмүүсийн уг чанарыг болон ертөнцийн хүмүүсийн бүх завхралыг мэддэг. Энэ нь Түүний оршихуй юм. Тэр дэлхий ертөнцтэй харьцдаггүй хэдий ч дэлхий ертөнцтэй харьцах дүрмийг мэддэг, учир нь Тэр хүний уг чанарыг бүрэн ойлгодог билээ. Хүний нүдээр харж, чихээр сонсох аргагүй өнгөрсөн болон өнөөдрийн Сүнсний ажлын тухай Тэр мэднэ. Үүнд амьдралын гүн ухаан бус мэргэн ухаан болон хүмүүсийн хувьд ойлгоход хэцүү санагддаг гайхамшиг багтдаг. Энэ нь Түүний оршихуй бөгөөд хүмүүст ил, бас хүмүүсээс нуугдмал байдаг. Тэрээр ер бусын хүн юу болохыг илэрхийлдэггүй, харин Сүнсний төрөлх шинж чанар ба оршихуйг илэрхийлдэг. Тэрээр дэлхийг тойрон аялдаггүй боловч бүх зүйлийг нь мэддэг. Тэр мэдлэггүй, ойлголтгүй “хүн дүрст сармагчнууд”-тай холбогддог боловч мэдлэгээс өндөр, агуу хүмүүсээс дээгүүр үгийг илэрхийлдэг. Тэрээр хүн чанаргүй, хүн төрөлхтний ёс журам болон

амьдралыг ойлгодоггүй мулгуу, хөшүүн бүлэг хүмүүсийн дунд амьдардаг боловч хэвийн хүн чанарыг амьдран харуулахыг хүн төрөлхтнөөс хүсэхийн зэрэгцээ хүн төрөлхтний адгийн, дорд хүн чанарыг илчилдэг. Энэ бүхэн бол Түүний оршихуй бөгөөд мах цуснаас бүрдсэн ямар ч хүнээс дээр юм. Түүний хувьд, ярвигтай, төвөгтэй, бузар булай нийгмийн амьдралыг туулах шаардлагагүйгээр хийх хэрэгтэй ажлаа хангалттай хийж, завхарсан хүн төрөлхтний мөн чанарыг бүрэн илчилдэг. Тийм бузар булай нийгмийн амьдрал Түүний махбодыг босгон байгуулдаггүй. Түүний үг, ажил нь хүний дуулгаваргүй байдлыг л илчилдэг бөгөөд дэлхий ертөнцтэй харьцахад зориулсан туршлага, сургамжаар хүнийг хангадаггүй. Тэрээр хүнийг амиар хангахдаа нийгэм болон хүний гэр бүлийг мөрдөн шалгах шаардлагагүй байдаг. Хүнийг илчилж, шүүх нь Түүний махбодын туршлагын илэрхийлэл биш; харин хүний дуулгаваргүй байдлыг аль хэдийн мэдэж, хүн төрөлхтний завхралд зэвүүцсэний дараа хүний шударга бус байдлыг илчлэх явдал юм. Түүний хийдэг ажил нь бүгд Түүний зан чанарыг хүнд илчилж, Түүний оршихуйг илэрхийлэх явдал юм. Тэр л энэ ажлыг хийж чадна; энэ нь мах, цуснаас бүтсэн хүний хийж чадах зүйл биш. Түүний ажлаас хүмүүс Тэр ямар төрлийн хүн бэ гэдгийг таньж чадахгүй. Бас Түүний ажилд үндэслэн Түүнийг бүтээгдсэн хүн хэмээн ангилж чадахгүй. Түүний оршихуй нь Түүнийг бүтээгдсэн хүн хэмээн ангилах аргагүй болгодог. Хүн Түүнийг хүн биш гэж л тооцож чадах боловч ямар ангилалд оруулахаа мэддэггүй тул Бурхан гэж ангилахаас өөр аргагүйд хүрдэг. Хүний хувьд ингэх нь үндэслэлгүй зүйл биш, учир нь Бурхан хүний хийж чадахгүй маш их ажлыг хүмүүсийн дунд хийсэн билээ.

Бурханы хийдэг ажил Түүний махбодын туршлагыг төлөөлдөггүй; хүний хийдэг ажил хүний туршлагыг төлөөлдөг. Хүн бүр хувийн туршлагынхаа тухай ярьдаг. Бурхан үнэнийг шууд илэрхийлж чадна, харин хүн зөвхөн үнэнийг туулсныхаа дараа холбогдох туршлагыг илэрхийлж чадна. Бурханы ажилд дүрэм гэж үгүй бөгөөд цаг хугацаа, газар зүйн хил хязгаарт баригддаггүй. Тэр хэзээ ч, хаана ч Өөрийнхөө юу болохыг илэрхийлж чадна. Тэр хүссэнээрээ ажилладаг. Хүний ажилд нөхцөл байдал, орчин гэж бий; эс бөгөөс хүн ажиллаж чадахгүй, бас Бурханы тухай мэдлэг, үнэний тухай туршлагаа илэрхийлж чадахгүй. Бурханы Өөрийн ажил уу, хүний ажил уу гэдгийг танихын тулд чи энэ хоёрын ялгааг л харьцуулах ёстой. Хэрвээ Бурханы Өөрийн хийдэг ажил гэж байхгүй, зөвхөн хүний ажил л байсан бол чи хүмүүсийн сургаал нь өндөр бөгөөд хэн ч үүнд хүрч чаддаггүй гэдгийг мэдэх болно; тэдний ярианы өнгө, аливааг зохицуулах зарчим, ажилдаа туршлагажсан, тогтвортой байдал нь бусдын хувьд хүршгүй байдаг. Та нар бүгд хэв чанар сайтай, өндөр дээд мэдлэгтэй энэ хүмүүсийг гайхан биширдэг боловч Бурханы ажил болон үгээс чи хүн чанар нь хэр өндөр болохыг харж чаддаггүй. Тэр харин ч энгийн бөгөөд ажиллах үедээ хэвийн, бодитой байдаг ч мөнх бус хүмүүсийн хувьд бас хэмжээлшгүй байдаг, тиймээс хүмүүс Түүнийг нэг талаар биширч хүндэлдэг. Магадгүй хүний ажлын туршлага, төсөөлөл, оюун дүгнэлт нэлээд өндөр, хүн чанар нь нэлээд сайн байж болох юм; ийм шинж чанар нь хүмүүсийн бахдал бишрэлийг

л олж авдаг боловч тэдэнд хүндлэл болон айдас түгшүүр төрүүлдэггүй. Сайн ажиллаж чаддаг, ялангуяа гүн туршлагатай, үнэнийг хэрэгжүүлж чаддаг хүмүүсийг бүгд биширдэг боловч тэд биширч, атаархахаас бус, огт эмээдэггүй. Гэхдээ Бурханы ажлыг туулсан хүмүүс Бурханыг биширдэггүй; харин ч Бурханы ажил бол хүний хүрч чадахааргүй, хүнд ойлгогдошгүй, шинэлэг гайхалтай гэдгийг мэдэрдэг. Хүмүүс Бурханы ажлыг туулах үедээ Тэр бол хэмжээлшгүй, ухаалаг, гайхалтай гэдгийг эхлээд мэдэж, өөрийн эрхгүй Түүнийг хүндэлж, Түүний хийдэг ажлын нууцыг мэдэрдэг ба үүнд хүний оюун ухааны мэдлэгийн хүрээ хүрэхээргүй юм. Хүмүүс зөвхөн Түүний шаардлагад нийцэж, Түүний хүслийг биелүүлж чаддаг байхыг л хүсдэг; тэд Түүнээс давахыг хүсдэггүй, учир нь Түүний хийдэг ажил хүний бодол, төсөөллөөс хамаагүй давуу бөгөөд хүн оронд нь хийж чадахгүй. Хүн өөрөө ч хангалтгүй байдлаа мэддэггүй атал Бурхан шинэ замыг нээж, хүнд шинэ, илүү сайхан ертөнцийг авчрахаар ирдэг тул хүн төрөлхтөн шинэ ахиц дэвшилд хүрч, шинээр эхэлдэг. Бурханы талаар хүмүүсийн мэдэрдэг зүйл бишрэл биш, харин ч зөвхөн бишрэлээр зогсохгүй. Тэдний хамгийн гүнзгий туршлага нь хайр, хүндлэл байдаг; Бурхан бол үнэхээр гайхалтай гэдэг мэдрэмж юм. Тэрээр хүний хийж чадахгүй ажлыг хийж, хэлж чадахгүй зүйлийг хэлдэг. Бурханы ажлыг туулсан хүмүүс үргэлж үгээр илэрхийлэхийн аргагүй мэдрэмжтэй байдаг. Илүү гүнзгий туршлагатай хүмүүс Бурханыг гэх хайрыг ойлгож чаддаг; тэд Бурханы хайр татам байдлыг мэдэрч, Түүний ажил маш ухаалаг, маш гайхалтай гэдгийг мэдэрдэг, улмаар тэдний дунд хязгааргүй их хүч үүсдэг. Энэ бол айдас, эсвэл түр зуурын хайр, хүндлэл биш, харин хүнийг гэсэн Бурханы энэрэл, хүлээцтэй байдлын тухай гүн гүнзгий мэдрэмж юм. Гэвч, Түүний гэсгээлт, шүүлтийг туулсан хүмүүс сүр жавхланг нь мэдэрч, Тэр ямар ч халдлагыг тэвчдэггүй гэдгийг мэдэрдэг. Түүний ихээхэн ажлыг туулсан хүмүүс хүртэл Түүнийг ойлгож чаддаггүй; Түүнийг үнэн голоосоо хүндэлдэг бүх хүн Бурханы ажил хүний үзэлтэй нийцдэггүй, хүний үзэлтэй үргэлж сөргөлддөг гэдгийг мэддэг. Хүмүүс бишрэлээр дүүрэн байж, Өөрийг нь дагаж байгаа мэт царайлах нь Түүнд хэрэггүй; харин ч жинхэнэ хүндлэл, жинхэнэ дуулгавартай байдал л хэрэгтэй. Бурханы ихээхэн ажилд, жинхэнэ туршлагатай хэн боловч Бурханыг хүндэлдэг ба энэ нь зүгээр нэг бишрэлээс илүү юм. Хүмүүс Бурханы гэсгээлт, шүүлтийн ажлаас үүдэн Түүний зан чанарыг харсан бөгөөд тиймээс зүрхнийхээ угаас Бурханыг хүндэтгэн биширдэг. Бурханыг хүн хүндэлж, дуулгавартай дагах учиртай, учир нь Түүний оршихуй болон зан чанар бүтээгдсэн зүйлийнхтэй адилгүй, үүнээс дээгүүр юм. Бурхан бол өөрөө оршин тогтнодог, үүрд мөнхийн, бүтээгдсэн бус зүйл бөгөөд Бурханыг л хүндэлж, дуулгавартай дагавал зохино; хүн ийм шаардлага хангадаггүй. Тиймээс, Бурханы ажлыг туулсан, Бурханыг жинхэнээсээ мэддэг хүмүүс Түүнийг хүндэлдэг. Харин Түүний талаарх үзлээ орхидоггүй—Түүнийг Бурхан гэж ер үздэггүй хүмүүст—Бурханыг гэх хүндлэл байдаггүй, хэдийгээр тэд Бурханыг дагадаг ч байлдан дагуулагддаггүй; тэд бол угаасаа дуулгаваргүй хүмүүс юм. Бүтээгдсэн бүх зүйл Бүтээгчийг хүндэлдэг зүрх

сэтгэлтэй болж, Түүнд шүтэн мөргөж, ямар ч болзолгүйгээр Түүний ноёрхолд захирагдах үр дүнд хүрэхийн тулд Тэрээр ингэж ажилладаг. Энэ бол Түүний бүх ажлын хүрэхээр зорьж буй эцсийн үр дүн юм. Хэрвээ ийм ажлыг туулсан хүмүүс Бурханыг өчүүхэн ч хүндэлдэггүй бол, мөн урьдын дуулгаваргүй байдал нь огтхон ч өөрчлөгддөггүй бол таягдан хаягдах нь гарцаагүй. Хэрвээ Бурханыг гэх хүний хандлага зөвхөн бишрэх юм уу зайнаас хүндлэх явдал боловч Түүнийг өчүүхэн ч хайрладаггүй бол энэ нь Бурханыг хайрлах сэтгэлгүй хүний хүрсэн үр дүн бөгөөд ийм хүнд төгс болгуулах нөхцөл дутдаг. Хэрвээ ийм их ажил хүний жинхэнэ хайрыг олж авч чадахгүй бол ийм хүн Бурханыг олж аваагүй бөгөөд үнэнийг жинхэнээсээ эрэлхийлдэггүй. Бурханыг хайрладаггүй хүн үнэнийг хайрладаггүй, тиймээс Бурханыг олж авч чаддаггүй, Бурханы сайшаалыг хүртэж бүр ч чаддаггүй. Ийм хүмүүс Ариун Сүнсний ажлыг яаж ч туулж, шүүлтийг яаж ч туулсан бай, Бурханыг хүндэлж чаддаггүй. Тэд бол уг чанар нь өөрчлөгдөшгүй, туйлын хорон муу зан чанартай хүмүүс юм. Бурханыг хүндэлдэггүй бүх хүн таягдан хаягдаж, шийтгэлийн бай болж, ёрын мууг үйлддэг хүмүүсийн адилаар шийтгүүлж, зөв шударга бусыг үйлдсэн хүмүүсээс ч илүү зовох болно.

БУРХАНЫ АЖЛЫН ГУРВАН ҮЕ ШАТЫГ МЭДЭХ НЬ БУРХАНЫГ МЭДЭХ ЗАМ ЮМ

Хүн төрөлхтнийг удирдах ажил нь гурван үе шатанд хуваагддаг, энэ нь хүн төрөлхтнийг аврах ажил гурван үе шатанд хуваагддаг гэсэн үг юм. Энэ гурван үе шат нь дэлхийг бүтээх ажлыг агуулдаггүй, харин Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе болон Хаанчлалын эрин үеийн ажлын гурван үе шат юм. Дэлхийг бүтээх ажил нь бүхий л хүн төрөлхтнийг бий болгох ажил байсан. Энэ нь хүн төрөлхтнийг аврах ажил байгаагүй бөгөөд хүн төрөлхтнийг аврах ажилтай ямар ч хамаагүй, учир нь дэлхий ертөнц бүтээгдэх үед хүн төрөлхтнийг Сатан ялзруулаагүй байсан тул хүн төрөлхтнийг аврах ажлыг гүйцэтгэх хэрэггүй байлаа. Хүн төрөлхтнийг аврах ажил нь хүн төрөлхтөн ялзарсан үеэс л эхэлсэн ба хүн төрөлхтнийг удирдах ажил ч бас хүн төрөлхтөн ялзарсан үеэс л эхэлсэн. Өөрөөр хэлбэл, хүнийг удирдах Бурханы удирдлага нь хүн төрөлхтнийг аврах ажлын үр дүнд эхэлсэн бөгөөд дэлхийг бүтээх ажлаас болж үүсээгүй. Хүн төрөлхтөн ялзарсан зан чанартай болсны дараа л удирдлагын ажил бий болсон, иймд хүн төрөлхтнийг удирдах ажил дөрвөн үе шат юм уу дөрвөн эрин үеийг биш, харин гурван хэсгийг агуулдаг. Зөвхөн энэ л зөв хэллэг юм. Сүүлчийн эрин үе төгсөх үед хүн төрөлхтнийг удирдах ажил бүрэн төгсгөлдөө очсон байх болно. Удирдлагын ажлын төгсгөл гэдэг нь бүх хүн төрөлхтнийг аврах ажил бүрэн дуусаж, тэр үеэс эхлэн хүн төрөлхтний хувьд энэ үе шат дууссан байх болно гэсэн үг юм. Бүх хүн төрөлхтнийг аврах ажилгүйгээр хүн төрөлхтнийг удирдах ажил гэж байхгүй, ажлын гурван үе шат ч гэж байхгүй. Яг

нарийндаа хүн төрөлхтний доройтлын улмаас, мөн хүн төрөлхтөнд аврал маш яаралтай хэрэгтэй байсан учраас л Ехова дэлхийн бүтээлийг төгсгөж, Хуулийн эрин үеийн ажлыг эхэлсэн. Тэр үед л хүн төрөлхтнийг удирдах ажил эхэлсэн, өөрөөр хэлбэл, тэр үед л хүн төрөлхтнийг аврах ажил эхэлсэн юм. “Хүн төрөлхтнийг удирдах” гэдэг нь газар дээр шинээр бүтээгдсэн хүн төрөлхтний (өөрөөр хэлбэл, хараахан ялзраагүй хүн төрөлхтний) амьдралыг чиглүүлэх гэсэн үг биш. Харин энэ нь Сатаны ялзруулсан хүн төрөлхтнийг аврах, өөрөөр хэлбэл, ялзарсан хүн төрөлхтнийг өөрчлөх явдал юм. Энэ нь “хүн төрөлхтнийг удирдахын” утга учир билээ. Хүн төрөлхтнийг аврах ажил нь дэлхийг бүтээх ажлыг агуулдаггүй учраас хүн төрөлхтнийг удирдах ажил ч бас дэлхийг бүтээх ажлыг агуулдаггүй, харин дэлхийн бүтээлээс ангид ажлын гурван үе шатыг хамардаг. Хүн төрөлхтнийг удирдах ажлыг ойлгохын тулд, гурван үе шатны ажлын түүхийг мэдэж байх шаардлагатай—энэ бол аврагдахын тулд хүн бүрийн мэдэж байх ёстой зүйл юм. Бурханы бүтээл болохын хувьд та нар хүнийг Бурхан бүтээсэн гэдгийг мэдэх ёстой, хүн төрөлхтний ялзралын эх сурвалжийг, түүнчлэн хүний аврагдах үйл явцыг мэдэх ёстой. Та нар Бурханы тааллыг хүртэхийн тулд дүрэм журмын дагуу хэрхэн үйлдэхийг л мэддэг боловч Бурхан хүн төрөлхтнийг хэрхэн авардаг талаар болон хүн төрөлхтний ялзралын эх сурвалжийн талаар мэдэхгүй бол Бурханы бүтээлийн хувиар та нарт дутагдаж байгаа зүйл энэ юм. Чи Бурханы удирдлагын ажлын илүү өргөн хүрээний талаар мэдэхгүй мөртөө хэрэгжүүлж болох эдгээр үнэнийг ойлголоо гээд сэтгэл ханах ёсгүй—ингэдэг бол чи хэтэрхий ягшмал үзэлтэй юм. Ажлын гурван үе шат нь Бурхан хүнийг удирдахын дотоод түүх, бүхий л дэлхий ертөнцийн сайн мэдээний ирэлт, бүх хүн төрөлхтний дундах хамгийн агуу нууц төдийгүй сайн мэдээг түгээх суурь билээ. Хэрвээ чи зөвхөн өөрийн амьтай холбоотой энгийн үнэнийг ойлгоход анхааралаад бүх нууц болон үзэгдлээс хамгийн агуу нь болох энэ зүйлийн талаар юу ч мэдэхгүй бол чиний амь харахаас цаашгүй, гологдол бараатай адил байх бус уу?

Хүн зөвхөн хэрэгжүүлэлт дээр л төвлөрөөд Бурханы ажил болон хүний мэдэх ёстой зүйлийг хоёрдогч зүйл гэж үзвэл ялихгүй юманд ямааны гарз болох биш үү? Чи мэдэх ёстой зүйлээ мэдэх ёстой; хэрэгжүүлэх ёстой зүйлээ хэрэгжүүлэх л ёстой. Энэ л үнэнийг эрж хайдаг хүн юм. Сайн мэдээ түгээх цаг чинь ирэхэд хэрвээ чи, Бурхан бол агуу бөгөөд зөвт Бурхан, дээдийн дээд Бурхан, ямар ч агуу хүнтэй харьцуулшгүй Бурхан, Тэр бол бүхнээс дээд Бурхан… хэмээх эдгээр хамаа намаагүй, өнгөц үгийг хэлж, чухал ач холбогдолтой, мөн чанартай үг хэлж тун чадахгүй байвал; хэрвээ чи Бурханыг мэдэх талаар юм уу Бурханы ажлын талаар хэлэх үггүй, түүнчлэн үнэнийг тайлбарлаж, хүнийг дутагдаж байгаа зүйлээр нь хангаж чадахгүй бол чам шиг хүн үүргээ сайн биелүүлж чадахгүй. Бурханд гэрчлэл хийж, хаанчлалын сайн мэдээ түгээх нь тийм ч энгийн зүйл биш. Чи эхлээд үнэнээр болон ойлгох ёстой үзэгдлээр зэвсэглэх ёстой. Чи Бурханы ажлын өөр өөр талуудын үзэгдэл болон үнэний талаар тодорхой мэддэг болох үедээ зүрх

сэтгэлдээ Бурханы ажлыг мэдэж авах бөгөөд зөвт шүүлт ч бай, цэвэршүүлэлт ч бай, Бурхан юу хийхээс үл хамааран хамгийн агуу үзэгдлийг өөрийн суурь болгон эзэмшиж, хэрэгжүүлэх зөв үнэнийг мөн эзэмших ба ингэснээр Бурханыг эцсээ хүртэл дагаж чадна. Бурхан ямар ч ажил хийлээ гэсэн ажлынх нь зорилго өөрчлөгддөггүй, Түүний ажлын гол цөм өөрчлөгддөггүй бөгөөд хүний төлөө гэх Түүний хүсэл өөрчлөгддөггүй гэдгийг чи мэдэх ёстой. Түүний үг хэчнээн хатуу байсан ч, орчин нөхцөл хэчнээн бэрх байсан ч Түүний ажлын зарчим өөрчлөгдөхгүй ба хүнийг аврах Түүний санаа зорилго өөрчлөгдөхгүй. Энэ нь хүний төгсгөл юм уу хүний хүрэх газрын талаарх илчлэлийн ажил биш, сүүлчийн шатны ажил биш, Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөг төгсгөх ажил биш л бол, мөн Тэрээр хүнийг хүн болгох цаг үед байгаа л бол Түүний ажлын гол цөм өөрчлөгдөхгүй. Түүний ажлын гол цөм үргэлж хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг; Бурханд итгэх итгэлийн чинь суурь энэ байх ёстой. Ажлын гурван үе шатны зорилго нь бүх хүн төрөлхтнийг аврах буюу Сатаны эзэмшлээс хүнийг бүрэн аврах явдал юм. Ажлын гурван үе шат нь дор бүрнээ өөр өөр зорилго, ач холбогдолтой хэдий ч тус бүрдээ хүн төрөлхтнийг аврах ажлын нэг хэсэг бөгөөд хүн төрөлхтний шаардлагаас хамааран явагдсан авралын өөр өөр ажил билээ. Чи ажлын энэ гурван үе шатны зорилгыг мэддэг болмогцоо ажлын үе шат бүрийн ач холбогдлыг хэрхэн ойлгохоо мэддэг болж, Бурханы хүслийг хангалуун байлгахын тулд хэрхэн үйлдэхээ ойлгох болно. Хэрвээ чи энэ цэгт хүрч чадвал энэхүү хамгийн агуу үзэгдэл Бурханд итгэх итгэлийн чинь суурь болно. Чи зөвхөн хэрэгжүүлэх амархан замыг юм уу гүн гүнзгий үнэнийг эрж хайх ёсгүй, харин үзэгдлийг хэрэгжүүлэлттэй хослуулах ёстой, тэгснээр хэрэгжүүлж болох үнэн болон үзэгдэлд үндэслэсэн мэдлэг хоёулаа байх болно. Тэр үед л чи үнэнийг бүрэн дүүрэн эрэлхийлдэг хүн болно.

Ажлын гурван үе шат нь Бурханы бүхий л удирдлагын гол цөм бөгөөд Бурханы зан чанар болон Тэр юу болох нь ажлын гурван үе шатаар илэрхийлэгддэг. Бурханы ажлын гурван үе шатыг мэддэггүй хүмүүс нь Бурхан Өөрийнхөө зан чанарыг хэрхэн илэрхийлдгийг ухаарч чаддаггүй, мөн Бурханы ажлын мэргэн ухааныг ч мэддэггүй. Тэд бас хүн төрөлхтнийг авардаг Түүний олон арга зам болон бүх хүн төрөлхтний төлөөх Түүний хүслийн талаар мэдэхгүй хэвээр үлддэг. Ажлын гурван үе шат нь хүн төрөлхтнийг аврах ажлын бүрэн илэрхийлэл билээ. Ажлын гурван үе шатыг мэддэггүй хүмүүс Ариун Сүнсний ажилладаг олон янзын арга зам болон зарчмыг мэдэхгүй байх болно, мөн ажлын тодорхой нэг үе шатнаас үлдсэн дүрэм журмыг л чандлан баримталдаг хүмүүс нь Бурханыг дүрэм журмаар хязгаарладаг хүмүүс бөгөөд Бурханд итгэх тэдний итгэл тодорхойгүй байдаг. Тийм хүмүүс хэзээ ч Бурханы авралыг хүлээн авахгүй. Бурханы ажлын гурван үе шат л Бурханы бүхий л зан чанарыг бүрэн илэрхийлж чадна, мөн бүх хүн төрөлхтнийг аврах Бурханы санаа зорилго болон хүн төрөлхтний авралын бүхий л үйл явцыг бүрэн дүүрэн илэрхийлж чадна. Энэ бол Бурхан Сатаныг ялж, хүн төрөлхтнийг олж авсны баталгаа, Бурханы ялалтын баталгаа, мөн Бурханы бүхий л зан чанарын

илэрхийлэл юм. Бурханы ажлын гурван үе шатнаас нэг үе шатыг нь л ойлгодог хүмүүс Бурханы зан чанарын зөвхөн нэг хэсгийг л мэддэг. Ажлын энэ нэг л үе шат нь хүний үзэлд дүрэм журмыг амархан бий болгож, Бурханыг амархан тодорхойлдог ба Бурханы зан чанарын энэ ганц хэсгийг Бурханы бүхий л зан занарын төлөөлөл болгон хэрэглэдэг. Түүнчлэн хүний ихэнх төсөөлөл дотроо холилдсон байдаг, ингэснээр хүн Бурханы зан чанар, оршихуй, мэргэн ухаан болон Бурханы ажлын зарчмыг хязгаарлагдмал цар хүрээн дотор чандлан хязгаарлаж, Бурхан нэг удаа ийм байсан бол үргэлж ийм хэвээрээ үлдэж, хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж итгэдэг. Ажлын гурван үе шатыг мэддэг, ойлгодог хүмүүс л Бурханыг үнэн зөв, бүрэн дүүрэн мэдэж чадна. Ядаж л тэд Бурханыг израильчуудын юм уу иудейчүүдийн Бурхан гэж тодорхойлохгүй, мөн Түүнийг хүн төрөлхтний төлөө үүрд загалмай дээр цовдлогдох Бурхан гэж үзэхгүй. Хэрвээ хүн Бурханыг ажлынх нь нэг үе шатнаас л мэдэж авбал мэдлэг нь хэтэрхий өчүүхэн бөгөөд далай дахь нэг дуслаас цаашгүй юм. Тийм биш бол шашны хуучинсаг үзэлтнүүд яагаад Бурханыг амьдаар нь загалмайд цовдлох юм бэ? Энэ нь, хүн Бурханыг тодорхой цар хүрээн дотор хязгаарладгаас болдоггүй гэж үү? Олон хүн Бурханы янз бүрийн өөр өөр ажлыг мэддэггүй учраас, түүнчлэн дуслын төдий мэдлэг, хоосон сургаалаар Ариун Сүнсний ажлыг хэмждэг учраас Бурханыг эсэргүүцэж, Ариун Сүнсний ажилд саад болдоггүй гэж үү? Тийм хүмүүсийн туршлага өнгөцхөн байдаг хэдий ч тэд уг чанартаа биеэ тоосон, өөрсдийгөө өөгшүүлсэн байдаг бөгөөд Ариун Сүнсний ажлыг басамжилж, Ариун Сүнсний сахилгажуулалтыг үл ойшоодог төдийгүй Ариун Сүнсний ажлыг “баталгаажуулахын” тулд өөрсдийн хуучирсан, ялихгүй ёс зүйг ашигладаг. Тэд бас дүр эсгэж, өөрсдийнхөө эрдэм мэдлэгтэй гэдэгт болон дэлхийг хөндлөн гулд туулах чадвартай гэдэгтээ бүрэн итгэлтэй байдаг. Тийм хүмүүс нь Ариун Сүнсний жигшин голдог хүмүүс биш гэж үү, мөн тэднийг шинэ эрин үе таягдан хаяхгүй гэж үү? Бурханы өмнө ирж, Түүнийг илт эсэргүүцдэг энэ хүмүүс бол зүгээр л хэчнээн гайхалтай болохоо үзүүлэхээр оролдож байгаа мэдлэггүй, мэдээлэлгүй өөдгүй амьтад биш үү? Тэд Библийн хомс мэдлэгээрээ дэлхийн “академид” цадиггүй авирлахыг хичээж, хүмүүст заах өнгөц сургаалаараа Ариун Сүнсний ажлыг өөрчлөхийг хичээж, үүнийг өөрсдийнхөө бодлын дагуу байлгахаар оролддог. Мөн алсын хараагүй юм байж Бурханы 6,000 жилийн ажлыг нэг дор хальт харахаар хичээдэг. Энэ хүмүүст дурдваас зохистой эрүүл ухаан гэж огт байхгүй? Үнэндээ хүн Бурханы талаар хэдий чинээ их мэдлэгтэй байна, Түүний ажлыг шүүхдээ төдий чинээ алгуурладаг. Цаашлаад тэд өнөөдрийн Бурханы ажлын талаарх өөрсдийн мэдлэгийг жаахан л ярьдаг боловч шүүмжлэх гэж яардаггүй. Хүмүүс Бурханыг хэдий чинээ бага мэднэ, төдий чинээ биеэ тоон, өөртөө хэт итгэж, Бурханы оршихуйг улам улайран тунхагладаг—гэвч тэд зөвхөн онол ярьдаг ба ямар ч бодит баримт байдаггүй. Тийм хүмүүс ямар ч үнэ цэнгүй. Ариун Сүнсний ажлыг тоглоом гэж үздэг хүмүүс хөнгөн хуумгай юм! Ариун Сүнсний шинэ ажилтай учрах үедээ хянуур байдаггүй, харин ам хуурайгүй чалчиж, хурдан

шүүдэг хүмүүс, Ариун Сүнсний ажлын зөв зүйтэй байдлыг дур зоргоороо үгүйсгэдэг, мөн доромжилж гутаадаг, ийм хүндлэлгүй хүмүүс Ариун Сүнсний ажлыг мэддэггүй бус уу? Цаашлаад тэд асар их биеэ тоосон, төрөлхийн бардам, задарсан хүмүүс биш гэж үү? Тийм хүмүүс Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн авах өдөр ирлээ ч гэсэн Бурхан тэднийг тэвчихгүй. Тэд Бурханы төлөө ажилладаг хүмүүсийг дорд үзээд зогсохгүй, Бурханыг Өөрийг нь доромжилдог. Цагаандаа гарсан тийм хүмүүс энэ эрин үед ч, дараагийн эрин үед ч уучлагдахгүй, тамд үүрд мөхөх болно! Тийм хүндлэлгүй, дурааараа хүмүүс Бурханд итгэж байгаа дүр үзүүлдэг ба хүмүүс ийм байх тусмаа Бурханы захиргааны зарлигийг амархан зөрчих магадлалтай байдаг. Төрөлхийн задарсан, хэзээ ч хэнд ч дуулгавартай байгаагүй, биеэ тоосон тэр хүмүүс бүгд энэ замаар алхдаг биш үү? Үргэлж шинээрээ, хэзээ ч хуучин байдаггүй Бурханыг тэд өдрөөс өдөрт эсэргүүцдэггүй гэж үү? Өнөөдөр та нар Бурханы ажлын гурван үе шатны чухал ач холбогдлыг яагаад мэдэх ёстойгоо ойлгох хэрэгтэй. Миний хэлж байгаа үг та нарт ач тустай бөгөөд зүгээр дэмий хоосон яриа биш. Хэрвээ та нар эдгээрийг зүгээр л морин дэл дээр давхингаа цэцэгсийг бахдах мэт уншвал Миний шаргуу ажил талаар өнгөрөх бус уу? Та нар дор бүрнээ өөрсдийн уг чанарыг мэдэх ёстой. Ихэнх хүн маргалдахдаа сайн байдаг ба онолын асуултуудад түгдрэлгүй хариулдаг боловч мөн чанартай холбоотой асуултуудад юу ч хэлж чаддаггүй. Өнөөдөр ч гэсэн та нар дэмий зүйл ярьж, хуучин зан чанараа өөрчилдөггүй ба та нарын ихэнх чинь илүү өндөр дээд үнэнд хүрэхийн тулд эрэлхийлдэг замаа өөрчлөхийг боддоггүй, харин идэвх зүтгэлгүй амьдардаг. Тийм хүмүүс Бурханыг яаж эцэст нь хүртэл дагаж чадах юм бэ? Та нар аргалаад замын төгсгөлд хүрлээ ч гэсэн, энэ нь та нарт ямар ашиг тустай байх юм бэ? Хэтэрхий оройтохоосоо өмнө санаагаа өөрчилж, нэг бол үнэхээр эрэлхийлж, эсвэл эртхэн больсон нь дээр. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр та нар бусдыг мөлжигч болно—та нар тийм дорд, жигшүүртэй үүрэг гүйцэтгэхийг хүсэж байна уу?

Ажлын гурван үе шат нь Бурханы бүхий л ажлын тэмдэглэл, хүн төрөлхтнийг аврах Бурханы авралын тэмдэглэл бөгөөд санаанаас зохиосон зүйл биш. Хэрвээ та нар Бурханы бүхий л зан чанарын талаарх мэдлэгийг эрж хайхыг үнэхээр хүсвэл Бурханы гүйцэтгэсэн ажлын гурван үе шатыг мэдэх ёстой, түүнчлэн ямар нэг үе шатыг нь орхигдуулах ёсгүй. Энэ бол Бурханыг мэдэхээр эрж хайдаг хүмүүсийн биелүүлэх ёстой наад захын зүйл юм. Бурханы талаарх жинхэнэ мэдлэгийг хүн өөрөө зохиож чадахгүй. Энэ нь хүний өөрийн төсөөлж чадах зүйл биш, мөн ганцхан хүнд зориулсан Ариун Сүнсний тусгай ивээлийн үр дүн ч биш. Харин энэ нь хүн Бурханы ажлыг туулсны дараа гардаг мэдлэг бөгөөд Бурханы ажлын баримтуудыг туулсны дараа л гарч ирдэг Бурханы тухай мэдлэг юм. Тийм мэдлэгийг амархан олж авч болдоггүй, үүнийг мөн заалгаж ч болдоггүй. Энэ нь бүхэлдээ хувийн туршлагатай холбоотой. Ажлын гурван үе шатны гол цөм нь хүн төрөлхтнийг аврах Бурханы аврал юм, гэхдээ авралын ажил дотор, ажиллах хэд хэдэн арга барил болон Бурханы зан чанарыг илэрхийлэх арга агуулагдаж байдаг. Үүнийг ялган

таних нь хүний хувьд хамгийн хэцүү байдаг ба хүн ойлгоход хэцүү байдаг. Эрин үеүдийн зааг, Бурханы ажил дахь өөрчлөлт, ажлын байршил дахь өөрчлөлт, энэ ажлын хүлээн авагч дахь өөрчлөлт гэх мэт нь бүгдээрээ ажлын гурван үе шатанд багтдаг. Ялангуяа, Ариун Сүнсний ажиллах арга зам дахь ялгаа, түүнчлэн Бурханы зан чанар, дүр, нэр, ялгамж чанар дахь хувиралт болон бусад өөрчлөлт нь бүгдээрээ ажлын гурван үе шатны нэг хэсэг юм. Ажлын нэг үе шат нь нэг хэсгийг л төлөөлж чаддаг ба тодорхой цар хүрээн дотор хязгаарлагддаг. Энэ нь бусад тал байтугай эрин үеүдийн зааг юм уу Бурханы ажилд гарсан өөрчлөлтийг агуулдаггүй. Энэ нь мэдээж илэрхий баримт юм. Ажлын гурван үе шат нь хүнийг аврах Бурханы ажлын бүрэн дүүрэн байдал билээ. Хүн бүхэн Бурханы авралын ажлаас Түүний ажил болон зан чанарыг мэдэх ёстой, энэ баримтгүйгээр Бурханы талаарх мэдлэг чинь хоосон үг, хийсвэр онолоос л бүрддэг. Тийм мэдлэг нь хүнийг үнэмшүүлж ч чадахгүй, байлдан дагуулж ч чадахгүй; энэ нь бодит байдалтай нийцэхгүй бөгөөд үнэн биш юм. Энэ нь маш элбэг арвин, чихэнд чимэгтэй байсан ч гэсэн, Бурханы төрөлх зан чанарын тухай мэдлэгтэй нийцэхгүй бол Бурхан чамайг өршөөхгүй. Тэр чиний мэдлэгийг сайшаахгүйгээр үл барам Түүнийг доромжилсон ял оноож чамайг залхаан цээрлүүлэх болно. Бурханыг мэдэх үгийг хөнгөн хуумгай ярихаар болчихдог юм биш. Чи хэлэмгий доломгой, уран үгтэй бөгөөд үг чинь харыг цагаан, цагааныг хар болтол маргаж чадахуйц үнэхээр ухаалаг байсан ч Бурханы тухай мэдлэгийг ярина гэдэг чиний чадвараас давна. Бурхан бол чиний яаран шүүж, хамаагүй магтаж, хайхрамжгүйгээр гүтгэж болдог нэгэн биш. Чи хаа хамаагүй хүн бүхнийг магтдаг хэр нь Бурханы эрхэм дээд нигүүлслийг дүрслэхэд тохирох үг олох гэж чармайдаг—энэ нь бүтэлгүйтсэн хүн бүрийн сурч авсан зүйл юм. Маш олон хэлний мэргэжилтэн Бурханыг дүрслэх чадвартай хэдий ч тэдний дүрсэлдэг зүйлийн үнэн зөв байдал нь, хязгаарлагдмал үгсийн сантай ч баялаг туршлага эзэмшсэн, Бурханд харьяалагддаг хүмүүсийн хэлсэн үнэний зууны нэгтэй л дүйцдэг. Тиймээс Бурханы талаарх мэдлэг нь үгийн ухаалаг хэрэглээ юм уу баялаг үгсийн санд биш, харин үнэн зөв, бодит байдалд оршдог бөгөөд хүний мэдлэг болон Бурханы тухай мэдлэг нь огтхон ч хамаагүй гэдгийг харж болно. Бурханыг мэдэх хичээл нь хүн төрөлхтний ямар ч байгалийн шинжлэх ухаанаас дээгүүр юм. Энэ нь Бурханыг мэдэхээр эрж хайж байгаа тун цөөн хүний л сурч чадах хичээл болохоос авьяас чадвартай ямар ч хүний хүрч чадах зүйл биш юм. Иймээс та нар Бурханыг мэдэх болон үнэнийг эрэлхийлэх явдлыг хүүхэд ч хийж чадах зүйл гэж үзэх ёсгүй. Чи гэр бүлийн амьдрал, ажил мэргэжил, гэрлэлтдээ бүрэн амжилт гаргасан байж болох ч үнэн болон Бурханыг мэдэх хичээлийн тухайд гэвэл үзүүлэх зүйл юу ч үгүй, юунд ч хүрээгүй байдаг. Та нарын хувьд үнэнийг хэрэгжүүлэх тун хэцүү бөгөөд Бурханыг мэдэх нь бүр ч том хэцүү асуудал гэж хэлж болно. Энэ нь та нарын бэрхшээл, мөн энэ нь бүх хүн төрөлхтөнд тулгардаг бэрхшээл юм. Бурханыг мэдэх үйлсэд зарим нэг ахиц гаргасан хүмүүсийн дотор, стандартад нийцэх бараг хэн ч байдаггүй. Бурханыг мэднэ гэдэг нь юу гэсэн үг болохыг, яагаад

Бурханыг мэдэх шаардлагатайг, Бурханыг мэдэхийн тулд ямар түвшинд хүрэх ёстойг хүн мэддэггүй. Энэ нь хүн төрөлхтний хувьд маш будилаантай зүйл бөгөөд үнэхээр хүн төрөлхтөнд тулгарсан хамгийн том оньсого болсон юм—хэн ч энэ асуултад хариулж чаддаггүй, хэн ч энэ асуултад хариулахыг хүсдэггүй, учир нь өнөөг хүртэл хүн төрөлхтний дотроос хэн ч энэ ажлын судалгаанд амжилт гаргаж байгаагүй. Ажлын гурван үе шатны оньсого хүмүүст тайлагдах үед Бурханыг мэддэг авьяастай бүлэг хүмүүс ээлж дараалан гарч ирж магад юм. Мэдээж ийм байгаасай гэж Би найдаж байна, түүнчлэн Би энэ ажлыг биелүүлэх явцдаа явж байгаа бөгөөд ойрын ирээдүйд тийм авьяастнууд гарч ирэхийг харна гэж найдаж байна. Тэд ажлын энэ гурван үе шатны баримтыг гэрчлэх хүмүүс болох ба мэдээж ажлын энэ гурван үе шатыг ч гэсэн гэрчлэх эхний хүмүүс байх юм. Гэхдээ Бурханы ажил төгсөх өдөр тийм авьяастнууд гарч ирэхгүй юм уу эсвэл бие махбодтой болсон Бурханаар төгс болгуулахыг биечлэн хүлээн авсан хүн ганц хоёрхон байгаа бол энэ нь хүнийг хамгаас их шаналган зовоож, харамсалд хүргэх зүйл болох болно. Гэхдээ энэ нь зүгээр л хамгийн муугаар бодсон тохиолдол юм. Юу ч болсон гэсэн, үнэхээр эрэлхийлдэг хүмүүс энэ ерөөлийг олж авч чадна гэж Би одоо ч найдаж байна. Цаг хугацааны эхлэлээс хойш ийм ажил урьд нь хэзээ ч байгаагүй; хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд ийм үйл ажиллагаа хэзээ ч тохиолдож байгаагүй. Хэрвээ чи үнэхээр Бурханыг мэддэг эхний хүмүүсийн нэг болж чадвал бүх бүтээл дундах хамгийн дээд нэр төрийн хэрэг болохгүй гэж үү? Энэ нь, хүн төрөлхтний дундаас Бурханд хамгаас илүү сайшаагдсан бүтээл биш гэж үү? Тийм ажлыг хийхэд амархан биш боловч эцэст нь үр дүндээ хүрэх болно. Хүйс, үндэс угсаанаасаа үл хамааран Бурханыг мэддэг бүх хүн бол эцэстээ Бурханы хамгийн агуу алдар сууг хүлээн авч, Бурханы эрх мэдлийг эзэмшдэг цорын ганц хүмүүс байх болно. Энэ бол өнөөдрийн ажил, мөн түүнчлэн ирээдүйн ажил билээ; энэ нь 6,000 жилийн ажил дахь эцсийн, хамгийн дээд ажил бөгөөд төрөл бүрийн хүнийг илчилдэг нэг төрлийн ажиллах арга зам юм. Хүнд Бурханыг мэдүүлэх ажлаар дамжин хүний өөр өөр зэрэглэл илчлэгддэг: Бурханыг мэддэг хүмүүс нь Бурханы ерөөлийг хүртэж, Түүний амлалтыг хүлээн авахад тохирдог байхад Бурханыг мэддэггүй хүмүүс Бурханы ерөөлийг хүртэж, Түүний амлалтыг хүлээн авахад тэнцдэггүй. Бурханыг мэддэг хүмүүс бол Бурханы дотнын хүмүүс бөгөөд Бурханыг мэддэггүй хүмүүсийг Бурханы дотнын хүмүүс гэж нэрлэж болохгүй; Бурханы дотнын хүмүүс нь Бурханы ямар ч ерөөлийг хүлээн авч чадна, харин Түүнтэй дотно биш хүмүүс Түүний ажлын юуг ч биелүүлж чадахгүй. Гай зовлон, цэвэршүүлэлт, шүүлт ч бай, эдгээр зүйл нь бүгд эцсийн эцэст хүнийг Бурханы талаарх мэдлэгт хүргэж, Бурханд захирагдахын төлөө байдаг. Энэ бол эцэстээ хүрэх цорын ганц үр дүн юм. Ажлын гурван үе шатыг бүгдийг нээлттэй болгох нь Бурханы талаарх хүний мэдлэгт ашигтай бөгөөд Бурханы талаар бүрэн дүүрэн, нэгд нэггүй мэдлэгийг олж авахад хүнд тусалдаг. Энэ бүх ажил хүнд тустай юм.

Бурханы Өөрийн ажил бол хүний мэдэх ёстой үзэгдэл юм, учир нь Бурханы ажлыг хүн биелүүлж чадахгүй ба хүн эзэмшдэггүй. Ажлын гурван үе шат нь

Бурханы удирдлагын бүрэн дүүрэн байдал бөгөөд хүний мэдэх ёстой хамгийн агуу үзэгдэл юм. Хэрвээ хүн энэ хамгийн агуу үзэгдлийг мэдэхгүй бол Бурханыг мэдэхэд амаргүй, Бурханы хүслийг ойлгоход амаргүй байдаг төдийгүй хүн энэ замаар алхахад улам бүр бэрх болно. Үзэгдэлгүйгээр хүн өнөөдрийг хүрч чадахгүй байх байсан. Өнөөдрийг хүртэл үзэгдэл л хүнийг хамгаалж, хамгийн агуу хамгаалалтаар хүнийг хангасан. Ирээдүйд та нарын мэдлэг илүү гүнзгийрэх ёстой бөгөөд ажлын гурван үе шатан дахь Түүний бүх хүслийг болон Түүний ухаалаг ажлын мөн чанарыг мэдэж авах ёстой. Энэ л та нарын жинхэнэ биеийн хэмжээ юм. Ажлын сүүлчийн үе шат нь дангаараа байдаггүй, харин өмнөх хоёр үе шаттайгаа хамт бүрдүүлсэн бүхэл нэг цогц болдог бөгөөд өөрөөр хэлбэл, ажлын гурван үе шатны нэгийг нь л хийгээд авралын бүх ажлыг дуусгах боломжгүй. Ажлын сүүлчийн үе шат нь хүнийг бүрэн аварч чадах хэдий ч хүнийг Сатаны нөлөөнөөс аврахад энэ ганц үе шатыг л дангаар нь хэрэгжүүлэх хэрэгтэй, ажлын өмнөх хоёр үе шат нь шаардлагагүй гэсэн үг биш. Гурван үе шатны аль ч ганц үе шатыг бүх хүн төрөлхтний мэдэх ёстой цорын ганц үзэгдэл гэж тогтоож болохгүй, учир нь авралын ажлын бүрэн бүтэн байдал нь ажлын гурван үе шат болохоос тэдгээрийн дундах ганц үе шат биш. Авралын ажил биелээгүй цагт Бурханы удирдлага бүрэн төгсөж чадахгүй байх болно. Бурханы оршихуй, зан чанар болон мэргэн ухаан нь авралын ажлын бүрэн бүтэн байдалд илэрхийлэгдсэн байдаг бөгөөд бүр эхнээсээ хүнд илчлэгдэлгүй, харин авралын ажилд аажмаар илэрхийлэгдэж ирсэн билээ. Авралын ажлын үе шат бүр Бурханы зан чанарын нэг хэсгийг болон Түүний оршихуйн нэг хэсгийг илэрхийлдэг; харин ажлын ямар ч үе шат Бурханы оршихуйн бүрэн дүүрэн байдлыг шууд, бүрэн илэрхийлдэггүй. Тиймээс ажлын гурван үе шат дууссаны дараа авралын ажил бүрэн төгсөнө, иймээс хүн Бурханы бүрэн дүүрэн байдлыг мэдэхдээ Бурханы ажлын гурван үе шатаас салж болохгүй. Ажлын нэг үе шатнаас хүн ердөө Бурханы ажлын ганц хэсэгт илэрхийлэгдсэн зан чанарыг нь л олж авдаг билээ. Энэ нь өмнөх ба дараах үе шатанд илэрхийлэгдсэн зан чанар болоод оршихуйг төлөөлж чадахгүй. Учир нь, хүн төрөлхтнийг аврах ажлыг нэг цаг үед, эсвэл нэг газарт тэр дор нь дуусгаж болдоггүй, харин энэ нь өөр өөр цаг үе, газрууд дахь хүний хөгжлийн түвшний дагуу аажмаар гүнзгийрдэг. Энэ нь үе шаттайгаар явагддаг ажил бөгөөд ганц үе шатанд дуусдаггүй. Иймээс Бурханы бүхий л мэргэн ухаан нь бие даасан нэг үе шатны оронд гурван үе шатанд биеждэг. Түүний бүхий л оршихуй болон бүхий л мэргэн ухаан нь энэ гурван үе шатанд оршдог бөгөөд үе шат бүр Түүний оршихуйг агуулж, Түүний ажлын мэргэн ухааны тэмдэглэл болдог. Хүн энэ гурван үе шатанд илэрхийлэгдсэн Бурханы бүхий л зан чанарыг мэдэх ёстой. Бурханы энэ бүх оршихуй нь бүх хүн төрөлхтөнд үнэхээр тун чухал байдаг ба хэрвээ хүмүүс Бурханыг шүтэхдээ үүнийг мэдэхгүй бол Буддаг шүтдэг хүмүүсээс ялгаагүй. Хүмүүсийн дундах Бурханы ажил бүх хүнд нээлттэй бөгөөд Бурханыг шүтэн мөргөдөг бүх хүн үүнийг мэддэг байх ёстой. Бурхан хүмүүсийн дунд авралын ажлын гурван үе шатыг хэрэгжүүлсэн учраас ажлын энэ гурван үе шатны туршид

Түүнд юу байгаа болон Тэр юу болохын илэрхийллийг хүн мэдэх ёстой. Энэ нь хүний заавал хийх ёстой зүйл юм. Бурхан хүний биелүүлж чадахгүй, мөн хүний мэдэх ёсгүй зүйлийг хүнээс нуудаг, харин Бурхан хүний мэдэх ёстой, хүний эзэмших ёстой зүйлийг хүнд үзүүлдэг. Ажлын гурван үе шат нь дор бүрнээ өмнөх үеийнхээ суурин дээр хийгддэг; энэ нь авралын ажлаас тусдаа бие даан хийгдсэн ажил биш. Эрин үед болон хэрэгжүүлэх ажилд асар их ялгаа байдаг хэдий ч гол цөм нь мөн л хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг ба авралын ажлын үе шат бүр нь өмнөхөөсөө алхам алхмаар гүнзгийрдэг. Ажлын үе шат бүр нь өмнөх ажлыг хүчингүй болгохгүй байх суурин дээр үргэлжилдэг. Ийм байдлаар Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй ажлаараа хүнд урьд өмнө нь хэзээ ч илэрхийлж байгаагүй зан чанарынхаа талуудыг байнга илэрхийлж, шинэ ажил, шинэ оршихуйгаа хүнд үргэлж илчилж байдаг бөгөөд шашны хуучинсаг үзэлтнүүд үүнийг эсэргүүцэхийн тулд боломжтой бүхнийг хийж, илт эсэргүүцдэг боловч Бурхан хийхээр зорьсон шинэ ажлаа үргэлж хийдэг. Түүний ажил үргэлж өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнээс үүдэн хүний эсэргүүцэлтэй үргэлж тулгарч байдаг. Гэхдээ Түүний зан чанар төдийгүй Түүний ажлын эрин үе, хүлээн авагчид ч бас үргэлж өөрчлөгдөж байдаг. Түүнчлэн Тэр үргэлж өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажлыг хийж, тэр ч байтугай өмнө нь хийсэн ажилтайгаа зөрчилдөж, харшилж байгаа мэт хүнд харагддаг ажлыг хэрэгжүүлж байдаг. Хүн нэг төрлийн ажил, хэрэгжүүлэх нэг арга замыг л хүлээн авч чаддаг. Тэдгээртэй зөрчилдсөн, эсвэл тэдгээрээс дээр ажил юм уу хэрэгжүүлэх аргыг хүлээн авахад хэцүү байдаг. Гэвч Ариун Сүнс үргэлж шинэ ажил хийж байдаг учраас Бурханы шинэ ажлыг эсэргүүцдэг шашны мэргэжилтнүүдийн бүлэг ээлж дараалан гарч ирдэг. Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй тухай мэдлэг хүнд байдаггүй, Бурханы ажлын зарчмын мэдлэг байдаггүй, түүнчлэн хүнийг авардаг Бурханы олон арга замын талаарх мэдлэг байдаггүй учраас л энэ хүмүүс мэргэжилтнүүд болсон. Тиймээс энэ нь Ариун Сүнснээс ирдэг ажил уу, эсвэл Бурханы Өөрийн ажил уу гэдгийг хүн огт ялган салгах чадваргүй байдаг. Энэ нь өмнө нь хэлсэн үгтэй таарч байвал хүлээн авч, өмнөх ажлаас ялгаатай байвал эсэргүүцэж голох хандлагыг олон хүн баримталдаг. Өнөөдөр та нар бүгдээрээ тийм зарчмыг мөрддөггүй гэж үү? Авралын ажлын гурван үе шат та нарт ямар ч агуу үр нөлөө үзүүлээгүй бөгөөд өмнөх хоёр үе шатны ажил нь эгээ л мэдэх хэрэггүй ачаа гэж итгэдэг хүмүүс байдаг. Хүмүүсийг будилуулахаас зайлсхийхийн тулд ажлын гурван үе шатны эхний хоёр үе шатыг олон түмэнд тунхаглах ёсгүй, харин аль болох хурдан нуух ёстой гэж тэд боддог. Ажлын өмнөх хоёр үе шатыг мэдэгдэх нь илүүц алхам, энэ нь Бурханыг мэдэхэд ямар ч нэмэргүй гэж ихэнх хүн итгэдэг—энэ бол та нарын үзэл. Өнөөдөр ийм маягаар үйлдэх нь зөв гэж та нар бүгд итгэдэг боловч Миний ажлын чухал ач холбогдлыг ухаарах өдөр та нарт ирнэ: Би ямар ч ач холбогдолгүй ажил хийдэггүй гэдгийг мэдэж ав. Би ажлын гурван үе шатыг та нарт тунхаглаж байгаа тул энэ нь та нарт ач тустай байж л таарна; ажлын энэ гурван үе шат нь Бурханы бүхий л

удирдлагын гол цөм тул орчлон ертөнц даяарх хүн бүрийн анхаарлыг татах нь гарцаагүй. Нэг өдөр та нар бүгдээрээ энэ ажлын чухал ач холбогдлыг ухаарах болно. Та нар Бурханы ажлын зарчмыг мэддэггүй, мөн Ариун Сүнсний ажилд хөнгөн хуумгай ханддаг учраас Бурханы ажлыг эсэргүүцэж, өөрсдийн үзлийг ашиглан өнөөдрийн ажлыг хэмждэг гэдгээ мэдэж ав. Та нар өөрсдийн үзэл болон төрөлхийн биеэ тоосон зангаасаа үүдэн Бурханыг эсэргүүцэж, Ариун Сүнсний ажилд саад болдог. Энэ нь Бурханы ажил буруугаас болдоггүй, харин та нар угаасаа хэтэрхий дуулгаваргүйгээс болдог. Зарим хүн Бурханд итгэсний дараа хүн хаанаас бий болсныг ч баттай хэлж чаддаггүй атлаа Ариун Сүнсний ажлын зөв, бурууг үнэлж, олон нийтийн өмнө үг хэлж зүрхэлдэг. Тэр ч байтугай тэд Ариун Сүнсний шинэ ажилтай элч нарт хүртэл сургаал айлдаж, гар хөлөө гозолзуулан, элий балай зүйл ярьдаг; тэдний хүн чанар хэтэрхий дорд бөгөөд тэдэнд өчүүхэн төдий ч эрүүл ухаан байдаггүй. Тийм хүмүүс Ариун Сүнсний ажилд гологдож, тамын галд шатаагдах өдөр ирэх бус уу? Тэд Бурханы ажлыг мэддэггүй, харин Түүний ажлыг шүүмжилж, мөн Түүнд хэрхэн ажиллахыг нь заахаар оролддог. Тийм ухаангүй хүмүүс Бурханыг яаж мэдэж чадах юм бэ? Хүн Бурханыг эрж хайж, мэдрэх явцдаа Түүнийг мэдэж авдаг; харин Бурханыг дураараа шүүмжлэх явцдаа Ариун Сүнсний гэгээрлээр дамжуулан мэдэж авдаг юм биш. Бурханы талаарх хүмүүсийн мэдлэг хэдий чинээ үнэн зөв байна, тэд Түүнийг төдий чинээ бага эсэргүүцдэг. Харин хүмүүс Бурханыг хэдий чинээ бага мэднэ, Түүнийг төдий чинээ амархан эсэргүүцдэг. Чиний үзэл, чиний хуучин уг чанар, чиний хүн чанар, зан байдал, ёс суртахуун, үзэл баримтлал бол Бурханыг эсэргүүцэх хөрөнгө бөгөөд ёс суртахуун нь завхарсан, хэв чанар нь өөдгүй, хүн чанар нь дорд болох тусмаа чи төдий чинээ Бурханы дайсан байдаг. Үзэл ихтэй, өөрийгөө зөвтгөдөг зан чанартай хүмүүс бие махбодтой болсон Бурханд бүр ч их дайсагнадаг ба тийм хүмүүс бол антихристүүд юм. Хэрвээ чиний үзлийг залруулахгүй бол энэ чинь үргэлж Бурханы эсрэг байх болно; чи хэзээ ч Бурхантай нийцэлтэй байж чадалгүй, үргэлж Түүнээс тусдаа байх болно.

Хуучин үзлээ хойш тавьснаар л чи шинэ мэдлэгийг олж авч чадна, гэхдээ хуучин мэдлэг нь хуучин үзэлтэй заавал адил байх албагүй. “Үзэл” гэдэг нь хүний төсөөлсөн, бодит байдалтай нийцэхгүй зүйлсийг хэлдэг. Хэрвээ хуучин мэдлэг нь хуучин эрин үед аль хэдийн хоцрогдсон бөгөөд хүнийг шинэ ажилд ороход нь саад болдог бол ийм мэдлэг ч бас үзэл юм. Хүн ийм мэдлэгт зөв хандлага баримталж чадвал, мөн хуучин, шинэ хоёрыг хослуулснаар Бурханыг хэд хэдэн өөр талаас нь мэдэж чадвал тэрхүү хуучин мэдлэг нь хүнд нэмэр болж, шинэ эрин үед орох үндэс суурь нь болдог. Бурханыг мэдэх хичээл нь, Бурханы шинэ ажлын бүх зохицуулалтад захирагдахын тулд Бурханыг мэдэх замд хэрхэн орох, Бурханыг мэдэхийн тулд ямар үнэнийг ойлгох ёстой, өөрийн үзэл болон хуучин зан чанараас хэрхэн ангижрах зэрэг олон зарчмыг эзэмшихийг чамаас шаарддаг. Хэрвээ чи эдгээр зарчмыг Бурханыг мэдэх хичээлд орох суурь болгон ашиглавал мэдлэг чинь улам бүр гүн гүнзгий болно. Хэрвээ чи ажлын гурван үе шатны талаар, өөрөөр

хэлбэл, Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний ажлын талаар тодорхой мэдлэгтэй бол, мөн хэрвээ чи Бурханы ажлын өмнөх хоёр үе шатыг одоогийн үе шаттай бүрэн хамааруулж, энэ нь нэг Бурханы хийсэн ажил юм гэдгийг харж чадвал хамгийн бат бэх суурь чинь энэ болно. Ажлын гурван үе шатыг нэг Бурхан хийсэн; энэ бол хамгийн агуу үзэгдэл бөгөөд Бурханыг мэдэх цорын ганц зам юм. Ажлын гурван үе шатыг Бурхан Өөрөө л хийж чадна, ямар ч хүн ийм ажлыг Түүний өмнөөс хийж чадахгүй—өөрөөр хэлбэл, эхлэлээс авхуулаад өнөөдрийг хүртэл Бурхан л Өөрийн ажлыг Өөрөө хийж чадна. Бурханы ажлын гурван үе шат хэдийгээр өөр өөр эрин үед, өөр өөр газарт явагдаж, мөн ажил бүр нь ялгаатай байсан ч энэ нь бүгд нэг Бурханы хийсэн ажил юм. Бүх үзэгдлийн дотроос хүний мэдэх ёстой хамгийн агуу үзэгдэл энэ бөгөөд хүн үүнийг бүрэн ойлговол бат зогсож чадна. Өнөөдөр төрөл бүрийн шашин болон урсгалд тулгараад байгаа хамгийн том асуудал бол Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, Ариун Сүнсний ажил болон Ариун Сүнсний бус ажлыг ялган салгаж чаддаггүй, иймээс өмнөх хоёр үе шатны ажилтай адилаар энэ үе шатны ажлыг ч бас Ехова Бурхан хийсэн эсэхийг тэд тодорхой харж чадахгүй. Хэдийгээр ихэнх хүмүүс Бурханыг дагадаг ч энэ нь зөв зам эсэхийг хүмүүс одоо ч тодорхой харж чадахгүй. Энэ зам нь Бурхан Өөрөө биечлэн удирддаг зам мөн эсэх, бие махбодтой болсон Бурхан бодит эсэхэд хүн санаа зовдог бөгөөд ийм зүйлсийг хэрхэн ялган таних талаар ихэнх хүнд ямар ч сэжүүр байдаггүй. Бурханыг дагадаг хүмүүс замыг тодорхойлж чаддаггүй бол ярьсан сургаалууд нь энэ хүмүүсийн дунд үр дүнгээ бүрэн өгч чадалгүй, ердөө хагас хугас үр нөлөөтэй байдаг, энэ нь хүмүүсийн амийн оролтод нөлөөлдөг. Хэрвээ хүн ажлын гурван үе шатнаас, эдгээр нь өөр өөр цаг үед, өөр өөр газарт, өөр өөр хүмүүсийн дунд Бурханы Өөрийн хийсэн ажил юм гэдгийг харж чадвал; мөн ажил нь өөр байсан ч энэ бүгдийг нэг Бурхан хийсэн ба энэ нь нэг Бурханы хийсэн ажил тул алдаа мадаггүй зөв байж таарна, хэдийгээр хүний үзэлтэй зөрөлдөж байсан ч энэ нь нэг Бурханы хийсэн ажил мөн гэдгийг үгүйсгэх аргагүйг харж чадвал; хэрвээ хүн, энэ нь нэг Бурханы ажил мөн гэдгийг баттай хэлж чадвал хүний үзэл дурдахын ч хэрэггүй, ердөө ялихгүй зүйл болох болно. Хүний үзэгдэл тодорхой бус бөгөөд хүн зөвхөн Еховаг Бурхан, Есүсийг Эзэн гэж л мэдэн, өнөөдрийн бие махбодтой болсон Бурханы тухайд сэтгэл нь хоёрддог учраас олон хүн Ехова болон Есүсийн ажлаас салж ядан, өнөөдрийн ажлын талаар олон үзэлд баригддаг ба ихэнх хүн үргэлж эргэлзэн, өнөөдрийн ажлыг нухацтай авч үздэггүй. Ажлын үл үзэгдэх өмнөх хоёр үе шатны талаар хүнд ямар ч үзэл байдаггүй, учир нь хүн ажлын өмнөх хоёр шатны бодит байдлыг ойлгодоггүй ба тэдгээрийг өөрийн биеэр хараагүй юм. Ажлын энэ үе шатуудыг харж чадахгүй учраас хүн хүссэнээрээ төсөөлдөг; хүн юу ч төсөөллөө гэсэн ийм төсөөллийг батлах баримт байдаггүй, мөн засаж залруулах хүн ч байдаггүй. Хүн зан аашаа зоргоор нь тавьж, сэрэмж болгоомжоо салхинд хийсгээд, төсөөлөлдөө умбадаг, мөн энэ төсөөллийг батлах ямар ч баримт байхгүй учраас ямар нэг үндэслэл бий эсэхээс үл хамааран хүний төсөөлөл нь “баримт” болдог.

Тиймээс хүн ой ухаандаа өөрийн төсөөлсөн Бурханд итгэн, бодит байдлын Бурханыг эрж хайдаггүй. Нэг хүнд нэг төрлийн итгэл байвал зуун хүний дунд зуун төрлийн итгэл байх болно. Хүн Бурханы ажлын бодит байдлыг хараагүй учраас тийм итгэлийг эзэмшдэг, учир нь тэр үүнийг зөвхөн чихээр сонссоноос биш, нүдээр үзээгүй. Хүн үлгэр, домог сонссон байдаг боловч Бурханы ажлын баримтын талаарх мэдлэгийг сонссон байх нь ховор. Тиймээс нэг жил итгэсэн хүмүүс өөрсдийн үзлээр Бурханд итгэдэг. Насан туршдаа Бурханд итгэсэн хүмүүс ч бас тэгдэг. Баримтыг харж чаддаггүй хүмүүс Бурханы талаарх үзэл бүхий итгэлээсээ хэзээ ч мултарч чадахгүй. Өөрийгөө хуучин үзлийн хүлээсээс чөлөөлж, шинэ хүрээнд орлоо гэж хүн итгэдэг. Бурханы жинхэнэ царайг харж чадахгүй хүмүүсийн мэдлэг бол үзэл, цуурхал л төдий гэдгийг хүн мэдэхгүй гэж үү? Хүн өөрийнхөө үзлийг алдаа мадаггүй зөв гэж бодон, эдгээр үзэл Бурханаас ирдэг гэж боддог. Өнөөдөр хүн Бурханы ажлыг нүдээр харах үедээ олон жилийн турш хуримтлагдсан үзлээ зоргоор нь тавьдаг. Өнгөрсөн үеийн төсөөлөл, санаа нь энэ үе шатны ажилд саад болсон ба ийм үзлийг орхиж, тийм санааг няцаах нь хүний хувьд хэцүү болсон. Алхам алхмаар явагдах энэ ажлын тухайд бол, өнөөдрийг хүртэл Бурханыг дагасан олон хүний үзэл улам бүр ноцтой болсон бөгөөд энэ хүмүүст бие махбодтой болсон Бурханы эсрэг эвлэршгүй үзэн ядалт аажмаар үүссэн. Энэхүү үзэн ядалтын эх сурвалж нь хүний үзэл, төсөөлөлд оршдог. Хүний үзэл, төсөөлөл нь өнөөдрийн ажил буюу хүний үзэлтэй нийцдэггүй ажлын дайсан болжээ. Баримт нь хүнд төсөөлөлдөө умбах боломж олгодоггүй, түүнчлэн хүн дурааараа няцаахыг зөвшөөрдөггүй, мөн хүний үзэл, төсөөлөл нь баримт байгааг тэвчдэггүй, цаашлаад хүн баримтын үнэн зөв байдлыг бодож үздэггүй, зүгээр л өөрийн үзлийг дураар нь тавьж, өөрийн төсөөллийг ашигладаг учраас л ийм зүйл болсон юм. Үүнийг хүний үзлийн алдаа л гэж хэлж болохоос биш, Бурханы ажлын алдаа гэж хэлж болохгүй. Хүн хүссэн бүхнээ төсөөлж болох ч Бурханы ажлын ямар ч үе шат юм уу үүний өчүүхэн төдий хэсгийг ч дурааараа няцааж болохгүй; Бурханы ажлын баримт нь хүн халдашгүй юм. Чи төсөөллөө зөнгөөр нь орхиж, тэр ч бүү хэл Ехова болон Есүсийн ажлын талаар сайхан түүхүүдийг эмхэтгэн гаргаж болох ч Ехова болон Есүсийн ажлын үе шат бүрийн баримтыг няцааж болохгүй; энэ бол зарчим төдийгүй захиргааны зарлиг бөгөөд эдгээр асуудлын чухал ач холбогдлыг та нар ойлгох ёстой. Ажлын энэ үе шат нь хүний үзэлтэй нийцдэггүй, харин ажлын өмнөх хоёр үе шатны хувьд тийм байгаагүй гэж хүн итгэдэг. Өөрийн төсөөлөлдөө хүн, өмнөх хоёр үе шатны ажил нь өнөөдрийн ажилтай яавч адилгүй гэж итгэдэг, гэвч Бурханы ажлын зарчмууд бүгд адилхан, Түүний ажил үргэлж бодитой байдаг бөгөөд эрин үеэс үл хамааран Түүний ажлын баримтыг эсэргүүцэж, сөргөлдөх хүн үргэлж асар олон гарч ирдэг гэснийг чи ер нь бодож үзэж байсан уу? Өнөөдөр энэ үе шатны ажлыг эсэргүүцэж, сөргөлдөж байгаа бүх хүн өнгөрсөн үед ч гэсэн Бурханыг эсэргүүцэж байсан нь эргэлзээгүй, учир нь тийм хүмүүс бүгд Бурханы дайсан юм. Бурханы ажлын баримтыг мэддэг

хүмүүс нь ажлын гурван үе шатыг нэг Бурханы ажил гэж үзэн, өөрсдийн үзлийг орхиж чаддаг. Эдгээр нь Бурханыг мэддэг хүмүүс бөгөөд ийм хүмүүс бол Бурханыг үнэхээр дагадаг хүмүүс юм. Бурханы бүхий л удирдлага төгсөх дөхөхөөр Бурхан бүх зүйлийг төрлийнх нь дагуу ангилах болно. Бүтээгчийн гар хүнийг бүтээсэн ба эцэст нь Тэр хүнийг Өөрийн эрх мэдэл дор бүрэн эргүүлэн авчрах ёстой; ажлын гурван үе шатны төгсгөл энэ юм. Эцсийн өдрүүдийн ажлын үе шат болон Израиль, Иудей дахь өмнөх хоёр үе шат нь бүхий л орчлон ертөнц дэх Бурханы удирдлагын төлөвлөгөө билээ. Хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй ба энэ нь Бурханы ажлын баримт юм. Хүмүүс энэ ажлын ихэнхийг туулаагүй, нүдээр үзээгүй хэдий ч баримт бол баримт хэвээрээ л байна, үүнийг ямар ч хүн үгүйсгэх аргагүй. Орчлон ертөнцийн газар болгонд байгаа Бурханд итгэдэг хүмүүс бүгдээрээ ажлын гурван үе шатыг хүлээн авах болно. Хэрвээ чи ажлын тодорхой нэг үе шатыг л мэддэг, нөгөө хоёр үе шатыг нь ойлгодоггүй, өнгөрсөн үед Бурханы хийсэн ажлыг ойлгодоггүй бол Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний бүх үнэнийг ярьж чадахгүй ба Бурханы талаарх мэдлэг чинь өрөөсгөл байна, учир нь чи Бурханд итгэдэг атлаа Түүнийг мэддэггүй, Түүнийг ойлгодоггүй тул Бурханд гэрчлэл хийхэд тохирохгүй. Эдгээр зүйлийн талаарх чиний одоогийн мэдлэг гүн гүнзгий ч бай, өнгөц ч бай, эцэст нь та нар мэдлэгтэй болж, бүрэн үнэмших ёстой, тэгээд бүх хүн Бурханы ажлыг бүхэлд нь харж, Бурханы эрх мэдэл дор захирагдана. Энэ ажлын төгсгөлд бүх шашин нэг болж, бүх бүтээл Бүтээгчийн эрх мэдэл дор эргэн ирж, бүх бүтээл нэгэн жинхэнэ Бурханыг шүтэн мөргөж, бүх муу шашин үгүй болж, хэзээ ч дахин гарч ирэхгүй.

Ажлын гурван үе шатыг яагаад ингэж ахин дахин дурддаг вэ? Эрин үеүдийн улиран өнгөрөх, нийгмийн хөгжил болон байгалийн өөрчлөлт бүгд ажлын гурван үе шатан дахь хувиралт өөрчлөлтийг дагадаг. Хүн төрөлхтөн өөрөө хөгждөггүй, харин Бурханы ажилтай хамт өөрчлөгддөг. Бүх бүтээл болон бүх шашин, бүх урсгалын хүмүүсийг нэг Бурханы эрх мэдэл дор аваачихын тулд Бурханы ажлын гурван үе шатыг дурддаг билээ. Чи ямар шашинд ч харьяалагддаг бай, эцэстээ бүгд Бурханы эрх мэдэл дор захирагдана. Бурхан Өөрөө л энэ ажлыг гүйцэтгэж чадна; шашны ямар ч тэргүүн үүнийг хийж чадахгүй. Дэлхий дээр хэд хэдэн томоохон шашин бий, эдгээр нь тус бүрдээ өөрийн тэргүүн буюу удирдагчтай байдаг бөгөөд дагалдагчид нь дэлхий даяар янз бүрийн улс орон, бүс нутгуудад тархсан байдаг; том ч бай жижиг ч бай, бараг улс орон бүр дотроо хэд хэдэн шашны урсгалтай байдаг. Гэвч дэлхий дээр хэчнээн ч шашин байлаа гэсэн, орчлон ертөнц дээрх бүх хүн эцэстээ нэг Бурханы удирдамж дор оршин тогтнодог бөгөөд тэдний оршин тогтнолыг шашны тэргүүн буюу удирдагчид залж чиглүүлдэггүй. Өөрөөр хэлбэл, шашны тодорхой нэг тэргүүн буюу удирдагч хүн төрөлхтнийг залж чиглүүлдэггүй; харин тэнгэр газар, бүх зүйлийг төдийгүй хүн төрөлхтнийг бүтээсэн Бүтээгч бүх хүн төрөлхтнийг удирддаг, энэ бол баримт юм. Дэлхийд хэд хэдэн том шашин байдаг хэдий ч тэдгээр нь хэчнээн агуу байсан ч бүгд Бүтээгчийн эрх мэдэл дор оршдог

бөгөөд аль нь ч энэ эрх мэдлийн хүрээг даван гарч чаддаггүй. Хүн төрөлхтний хөгжил, нийгмийн дэвшил, байгалийн шинжлэх ухааны хөгжил нь тус бүрдээ Бүтээгчийн зохицуулалттай салшгүй холбоотой бөгөөд энэ ажил нь шашны тодорхой нэг тэргүүний хийж чадах зүйл биш юм. Шашны тэргүүн бол тухайн шашныхаа удирдагч төдий л бөгөөд Бурханыг төлөөлж чадахгүй, тэнгэр газар, бүх зүйлийг бүтээсэн Нэгнийг ч төлөөлж чадахгүй. Шашны тэргүүн бүхий л шашин доторх бүх хүнийг удирдаж чаддаг боловч тэнгэрийн доорх бүх бүтээлийг захирч чадахгүй—энэ бол нийтээр хүлээн зөвшөөрсөн баримт юм. Шашны тэргүүн бол зүгээр л удирдагч бөгөөд Бурхантай (Бүтээгчтэй) эн зэрэгцэж чадахгүй. Бүх зүйл Бүтээгчийн гарт байдаг ба эцэстээ тэд бүгд Бүтээгчийн гарт эргэн очих болно. Хүн төрөлхтнийг Бурхан бүтээсэн бөгөөд ямар ч шашин бай, Бурханы эрх мэдэл дор эргэн очих болно—энэ нь гарцаагүй. Бурхан л бүх зүйлийн дотроос Хамгийн Дээд нь бөгөөд бүх бүтээлийн доторх хамгийн дээд захирагч хүртэл Түүний ноёрхол дор эргэн очих ёстой. Хүн хэчнээн ч өндөр байр суурьтай байлаа гэсэн хүн төрөлхтнийг тохиромжтой хүрэх газарт хүргэж чадахгүй, хэн ч бүх зүйлийг төрлөөр нь ангилж чадахгүй юм. Ехова Өөрөө хүн төрөлхтнийг бүтээж, тус бүрийг нь төрлөөр нь ангилсан ба төгсгөлийн цаг үе ирэхэд Тэр мөн л Өөрийн ажлыг Өөрөө хийж, бүх зүйлийг төрлөөр нь ангилна—энэ ажлыг Бурханаас өөр хэн ч хийж чадахгүй. Эхнээсээ өнөөдрийг хүртэл явагдсан ажлын гурван үе шатыг бүгдийг нь Бурхан Өөрөө хийсэн ба нэг Бурхан хийсэн. Ажлын гурван үе шатны баримт нь хүн төрөлхтнийг Бурхан удирдсан тухай баримт бөгөөд хэний ч үгүйсгэж чадахгүй баримт юм. Ажлын гурван үе шат төгсмөгц бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдаж, бүгд Бурханы эрх мэдэл дор эргэн очно, учир нь бүхий л орчлон ертөнц даяар зөвхөн энэ нэг Бурхан оршдог бөгөөд өөр шашин гэж байхгүй. Дэлхийг бүтээх чадваргүй нэгэн үүнийг төгсгөлд нь аваачиж чадахгүй, харин дэлхийг бүтээсэн Тэр үүнийг төгсгөлд нь аваачих чадвартай байх нь гарцаагүй. Тиймээс оюун ухаанаа хөгжүүлэхэд нь л хүнд тусалж чадахаас биш, эрин үеийг төгсгөж чадахгүй нэгэн бол Бурхан биш байх нь гарцаагүй, бас хүн төрөлхтний Эзэн биш байх нь гарцаагүй. Тэрээр ийм агуу ажил хийж чадахгүй; ийм ажлыг биелүүлж чадах цорын ганц нэгэн байдаг бөгөөд энэ ажлыг хийж чаддаггүй бүхэн бол Бурхан биш, дайснууд гэдэг нь гарцаагүй. Бүх муу ёрын шашин нь Бурхантай нийцдэггүй бөгөөд Бурхантай нийцдэггүй тул тэд Бурханы дайснууд мөн. Бүх ажлыг энэхүү нэг жинхэнэ Бурхан хийдэг, бүх орчлон ертөнцийг энэхүү нэг Бурхан захирдаг. Түүний ажил Израильд байна уу, Хятадад байна уу хамаагүй, энэ ажлыг Сүнс хийж байна уу, махбод хийж байна уу хамаагүй, бүгдийг нь Бурхан Өөрөө хийдэг ба өөр хэн ч орлож чадахгүй. Тэр бол бүх хүн төрөлхтний Бурхан учраас л эрх чөлөөтэй ажиллаж, ямар ч нөхцөл байдалд баригддаггүй—энэ бол хамгийн агуу үзэгдэл билээ. Чи Бурханы бүтээлийн хувиар Бурханы бүтээлийн үүргийг биелүүлж, Бурханы хүслийг ойлгохыг хүсвэл Бурханы ажлыг ойлгох ёстой, бүтээлийн төлөөх Бурханы хүслийг ойлгох ёстой, Түүний удирдлагын төлөвлөгөөг

ойлгох ёстой ба Түүний хийдэг ажлын бүх ач холбогдлыг ойлгох ёстой. Үүнийг ойлгодоггүй хүмүүс Бурханы бүтээл байхад тэнцэхгүй! Бурханы бүтээл болохын хувьд чи хаанаас ирснээ ойлгодоггүй, хүн төрөлхтний түүхийг болон Бурханы хийсэн бүх ажлыг ойлгодоггүй, түүнчлэн хүн төрөлхтөн өнөөг хүртэл хэрхэн хөгжсөнийг ойлгодоггүй, бүх хүн төрөлхтнийг хэн захирдгийг мэддэггүй бол үүргээ биелүүлж байна гэж тооцогдохгүй. Бурхан өнөөдрийг хүртэл хүн төрөлхтнийг удирдсаар ирсэн ба хүнийг газар дэлхий дээр бүтээснээсээ хойш хэзээ ч орхиогүй. Ариун Сүнс хэзээ ч ажиллахаа болиогүй, хүн төрөлхтнийг удирдахаа хэзээ ч зогсоогоогүй, хүн төрөлхтнийг хэзээ ч орхиогүй. Гэвч хүн төрөлхтөн Бурханыг мэдэх нь байтугай Бурхан байдгийг ч ухаардаггүй, Бурханы бүх бүтээлийн хувьд үүнээс гутамшигтай зүйл гэж байх уу? Бурхан Өөрөө хүнийг удирддаг боловч хүн Бурханы ажлыг ойлгодоггүй. Чи Бурханы бүтээл боловч өөрийнхөө түүхийг ойлгодоггүй, аян замд чинь хэн чамайг удирдаж ирснийг мэддэггүй, Бурханы хийсэн ажлыг мэдэхгүй бол Бурханыг мэдэж чаддаггүй. Хэрвээ чи одоо ч гэсэн мэдэхгүй хэвээр байвал чи хэзээ ч Бурханд гэрчлэл хийх эрхгүй. Өнөөдөр Бүтээгч дахин нэг удаа биечлэн бүх хүнийг удирдаж, Өөрийн мэргэн ухаан, төгс хүч, аврал болон гайхамшигт байдлыг бүх хүнд харуулдаг. Гэтэл чи одоо ч ухаарч ойлгоогүй—тиймээс чи аврал хүлээн авахгүй нэгэн биш гэж үү? Сатанд харьяалагддаг хүмүүс Бурханы үгийг ойлгодоггүй, харин Бурханд харьяалагддаг хүмүүс Бурханы дуу хоолойг сонсож чаддаг. Миний хэлж буй үгийг ухаарч, ойлгодог бүх хүн нь аврагдаж, Бурханд гэрчлэл хийх хүмүүс юм; Миний хэлж буй үгийг ойлгодоггүй бүх хүн нь Бурханд гэрчлэл хийж чадахгүй, таягдан хаягдах хүмүүс юм. Бурханы хүслийг ойлгодоггүй, Бурханы ажлыг ухаардаггүй хүмүүс Бурханыг мэдэж чадахгүй бөгөөд тийм хүмүүс Бурханыг гэрчилдэг хүн биш. Бурханд гэрчлэл хийе гэж хүсвэл Бурханыг мэдэх ёстой; Бурханы тухай мэдлэгт Бурханы ажлаар дамжин хүрдэг. Иймээс, эцсийн дүнд Бурханыг мэдмээр байвал Бурханы ажлыг мэдэх ёстой: Бурханы ажлыг мэдэх нь хамгийн чухал юм. Ажлын гурван үе шат төгсөх үед Бурханд гэрчлэл хийдэг хүмүүсийн бүлэг, өөрөөр хэлбэл, Бурханыг мэддэг хүмүүсийн бүлэг бүтээгдэнэ. Энэ хүмүүс бүгд Бурханыг мэдэх ба үнэнийг хэрэгжүүлж чаддаг байна. Тэд хүн чанар, эрүүл ухааныг эзэмшиж, Бурханы авралын ажлын гурван үе шатыг бүгд мэднэ. Энэ нь эцэстээ биелэх ажил бөгөөд энэ хүмүүс бол 6,000 жилийн удирдлагын ажлын биелэлт, Сатаны эцсийн ялагдлыг гэрчлэх хамгийн хүчтэй гэрчлэл юм. Бурханд гэрчлэл хийж чаддаг хүмүүс нь Бурханы амлалт, ерөөлийг хүлээн авч чадах бөгөөд Бурханы эрх мэдлийг эзэмшиж, Бурханд гэрчлэл хийдэг бүлэг, бүр эцсээ хүртэл үлдэх бүлэг хүмүүс байх болно. Та нар бүгдээрээ, эсвэл ердөө тэн хагас нь юм уу цөөн хэд чинь л энэ бүлгийн гишүүн болж магадгүй—энэ нь та нарын хүсэл болон эрэл хайгуулаас хамаардаг.

ЗАВХАРСАН ХҮН ТӨРӨЛХТӨНД БИЕ МАХБОДТОЙ БОЛСОН БУРХАНЫ АВРАЛ ИЛҮҮ ИХ ХЭРЭГТЭЙ

Бурханы ажлын бай нь Сатаны сүнс, эсвэл ямар нэг биегүй хоосон зүйл биш, харин махан биеэс бүтсэн, Сатаны завхралд өртсөн хүн учраас Бурхан махбод болсон билээ. Чухамдаа хүний махан бие завхарсан учраас Бурхан махан биетэй хүнийг Өөрийн ажлын бай болгосон; түүнчлэн, хүн завхралын бай учраас Бурхан авралын ажлынхаа бүх үе шатанд хүнийг Өөрийн ажлын цорын ганц бай болгосон юм. Хүн бол мах, цуснаас бүтсэн мөнх бус оршихуй бөгөөд хүнийг аварч чадах Нэгэн бол гагцхүү Бурхан билээ. Иймээс, ажлаа хийхийн тулд, Өөрийнхөө ажлыг илүү дээр үр дүнд хүргэхийн тулд Бурхан хүнтэй адил шинж чанартай махбод болох ёстой. Хүн махан биетэй, мөн нүглийг ялан дийлж, махан биеийг орхих чадваргүй учраас Өөрийн ажлыг хийхийн тулд Бурхан махбод болох ёстой. Бие махбодтой болсон Бурханы мөн чанар болон ялгамж чанар нь хүний мөн чанар, ялгамж чанараас асар их ялгаатай байдаг ч Түүний гадаад төрх хүнийхтэй адилхан; Тэрээр хэвийн хүний дүр төрхтэй, хэвийн хүний амьдралаар амьдардаг бөгөөд Түүнийг харсан хүмүүс хэвийн хүнээс ялгаж огт чадахгүй. Хэвийн хүн чанараар бурханлаг ажлаа хийхэд нь Түүнд энэхүү хэвийн төрх байдал, хэвийн хүн чанар хангалттай. Түүний махбод нь хэвийн хүн чанараар ажиллах боломж олгон, хүмүүсийн дунд ажлаа хийхэд нь тусалдаг, түүнчлэн хүмүүсийн дунд авралын ажлаа явуулахад нь Түүний хэвийн хүн чанар тусалдаг. Хэдийгээр Түүний хэвийн хүн чанар хүмүүсийн дунд ихээхэн шуугиан тарьсан ч тийм шуугиан Түүний ажлын хэвийн үр дүнд нөлөөлөөгүй. Товчхондоо Түүний хэвийн махбодын ажил нь хүнд дээд зэргийн ач тустай. Ихэнх хүмүүс Түүний хэвийн хүн чанарыг хүлээн зөвшөөрдөггүй хэдий ч Түүний ажил үр дүнд хүрч мөн л чадах ба Түүний хэвийн хүн чанарын ачаар эдгээр үр дүнд хүрдэг. Үүнд эргэлзэх юмгүй. Махбод дахь Түүний ажлаас хүн, Түүний хэвийн хүн чанарын талаар хүмүүсийн дунд байдаг үзлээс арав дахин, эсвэл бүр хэдэн арав дахин ихийг олж авдаг бөгөөд эцэстээ эдгээр үзэл нь бүгд Түүний ажилд залгиулдаг. Түүний ажлын хүрсэн үр дүн, өөрөөр хэлбэл, Түүний тухай хүний мэдлэг нь Бурханы талаарх хүний үзлээс хавьгүй их байдаг. Махбодоор хийдэг Түүний ажлыг төсөөлж, хэмжих аргагүй, учир нь Түүний махбод махан биетэй ямар ч хүнийхтэй адилгүй; гадаад бүрхүүл нь хэдий адилхан ч мөн чанар нь ижил биш. Түүний махбод хүмүүсийн дунд Бурханы талаарх олон үзлийг төрүүлдэг ч бас ихээхэн мэдлэг олж авах боломжийг хүнд олгодог ба тэр ч бүү хэл адилхан гадаад бүрхүүлтэй ямар ч хүнийг байлдан дагуулж чадна. Учир нь Тэр зүгээр ч нэг хүн биш, харин хүний гадаад бүрхүүлтэй Бурхан бөгөөд хэн ч Түүнийг бүрэн ухан мэдэж, ойлгож чадахгүй. Үл үзэгдэх, гарт үл баригдах Бурханыг бүгд хайрлаж, угтан авдаг. Хэрвээ Бурхан хүнд үл үзэгдэх Сүнс л байвал Бурханд итгэх нь хүнд маш хялбар байх болно. Хүн өөрийн төсөөллийг зөнд нь орхиж,

өөрийгөө баясгаж, жаргалтай байлгахын тулд дуртай дүр зургаа Бурханы дүр төрх болгон сонгож чадна. Ийм маягаар, хүмүүс өөрсдийнхөө Бурханы хамгийн дуртай зүйлийг болон хийгээсэй гэж хүсдэг зүйлийг нь ямар ч эргэлзээгүйгээр хийж болох юм. Үүнээс ч илүүтэйгээр, өөрөөс нь өөр хэн ч Бурханд үнэнч, сүсэгтэй биш бөгөөд бусад хүмүүс бүгд Харь үндэстний ноход, Бурханд үнэнч бус гэж хүмүүс итгэдэг. Энэ бол Бурханд итгэх итгэл нь тодорхойгүй агаад хоосон номлолд тулгуурласан хүмүүсийн эрж хайдаг зүйл гэж хэлж болно; тэдний эрж хайдаг зүйл хоорондоо тодийлөн ялгаагүй бүгд ижилхэн байдаг. Ердөө тэдний төсөөлөлд байгаа Бурханы дүр л өөр боловч мөн чанар нь үнэндээ адилхан.

Хүн Бурханд итгэхдээ хэнэггүй байдаг ба хүссэнээрээ Бурханд итгэдэг. Хүмүүс өөр хэний ч биш өөрийн Бурханд итгэж байгаа учраас энэ бол хэний ч саад болж чадахгүй “хүний эрх, эрх чөлөө” юм; энэ бол тэдний хувийн өмч бөгөөд бараг хүн бүр ийм төрлийн хувийн өмчтэй байдаг. Хүмүүс энэ өмчийг үнэт эрдэнэс гэж үздэг, харин Бурханы хувьд үүнээс илүү дорд, үнэ цэнгүй юу ч үгүй, учир нь хүний энэ хувийн өмч бол Бурханыг эсэргүүцдэгийн хамгийн илэрхий шинж юм. Бие махбодтой болсон Бурханы ажлаас болоод Бурхан, биет хэлбэртэй агаад хүн харж, хүрч болох махбод болдог. Тэрээр хэлбэргүй Сүнс биш, харин хүний хүрч, харж болох махбод юм. Гэсэн хэдий ч, хүмүүсийн итгэдэг Бурхадын ихэнх нь хэлбэргүй, бас хэлбэрт үл баригдах, биегүй бурхад байдаг. Ийм маягаар, бие махбодтой болсон Бурхан нь Бурханд итгэдэг ихэнх хүмүүсийн дайсан болсон бөгөөд үүний нэгэн адилаар, Бурхан бие махбодтой болсон баримтыг хүлээн зөвшөөрч чаддаггүй хүмүүс Бурханы дайснууд болсон. Хүн үзэлтэй байх нь түүний бодлоос, эсвэл тэрслүү байдлаас болдог юм биш, харин хүний энэ хувийн өмчөөс болж байгаа юм. Чухамдаа энэ өмчөөс болж ихэнх хүн үхдэг ба хүрч, харж болохгүй, бодит байдал дээр оршдоггүй энэхүү тодорхойгүй Бурхан хүний амийг сүйрүүлдэг. Хүний амийг сүйрүүлдэг нь бие махбодтой болсон Бурхан биш, тэнгэрийн Бурхан бүр ч биш, харин хүний өөрийнх нь төсөөллийн Бурхан юм. Бие махбодтой болсон Бурхан махбодод ирсний цорын ганц шалтгаан нь завхарсан хүний хэрэгцээнээс болсон билээ. Энэ нь Бурханы биш, хүний хэрэгцээнээс болдог бөгөөд Түүний бүх золиослол болон зовлон нь Бурханы Өөрийн ашиг тусын төлөө биш, харин хүн төрөлхтний төлөө байдаг. Бурханы хувьд ашиг, алдагдал, эсвэл шагнал гэж үгүй; Тэрээр хожмын ургацыг хураахгүй, харин анхнаасаа Өөрийнх нь байсан зүйлийг хураана. Хүн төрөлхтний төлөө Түүний хийдэг, золиосолдог бүхэн нь асар их шагнал олж авахын төлөө биш, харин гагцхүү хүн төрөлхтний төлөө байдаг. Хэдийгээр махбод дахь Бурханы ажил төсөөлөхийн аргагүй олон бэрхшээл агуулдаг ч эцэстээ хүрдэг үр дүн нь Сүнсний шууд хийсэн ажлаас хавьгүй илүү давдаг. Махбодын ажил ихээхэн бэрхшээл дагуулдаг бөгөөд махбодод Сүнстэй адил агуу ялгамж чанар байдаггүй, Сүнстэй адил ер бусын үйл хэргийг гүйцэтгэж чаддаггүй, Сүнстэй адил эрх мэдэл эзэмшиж бүр ч чаддаггүй. Гэхдээ бусдаас ялгарах юмгүй энэ махбодын хийсэн ажлын мөн чанар нь Сүнсний шууд хийсэн

ажлаас хавьгүй илүү бөгөөд энэхүү махбод Өөрөө бүх хүн төрөлхтний хэрэгцээ юм. Аврагдах хүмүүсийн хувьд, Сүнсний хэрэглээний үнэ цэн нь махбодынхоос хамаагүй доогуур байдаг: Сүнсний ажил уул нуруу, гол мөрөн, нуур, далай тэнгис гээд бүх орчлон ертөнцийг хамрах чадвартай атал махбодын ажил нь Өөрийн харилцдаг хүн бүртэй илүү ур дүнтэйгээр холбогддог. Үүнээс гадна биет хэлбэртэй Бурханы махбодыг хүн илүү их ойлгож, итгэж чадах бөгөөд энэ нь Бурханы тухай хүний мэдлэгийг улам гүнзгийрүүлж, хүнд Бурханы бодит үйл хэргийн талаар илүү гүн гүнзгий сэтгэгдэл үлдээж чаддаг. Сүнсний ажил нууц далд байдаг; мөнх бус хүмүүсийн хувьд үүнийг ухан ойлгоход хэцүү, харахад бүр ч хэцүү, иймээс тэд зөвхөн хий хоосон төсөөлөлд түшиглэж л чадна. Гэхдээ махбодын ажил хэвийн, бодит байдалд үндэслэдэг, баялаг мэргэн ухаантай байдаг бөгөөд энэ нь хүний нүдээр харж болох баримт юм; хүн Бурханы ажлын мэргэн ухааныг өөрийн биеэр туулах боломжтой, элбэг арвин төсөөллөө ашиглах шаардлагагүй байдаг. Энэ бол махбод дахь Бурханы ажлын үнэн зөв байдал болон жинхэнэ үнэ цэн мөн. Сүнс хүнд үл үзэгдэх зүйлсийг болон хүн төсөөлөхөд амаргүй зүйлсийг л хийж чаддаг, тухайлбал Сүнсний гэгээрэл, Сүнсний хөдөлгөлт, Сүнсний удирдамж зэрэг нь оюун ухаантай хүнийг ямар нэгэн тодорхой утга учраар хангадаггүй. Тэдгээр нь зөвхөн сэтгэл хөдөлгөх юм уу өргөн хүрээтэй утга учраар хангахаас биш, үгээр зааварчилгаа өгч чадахгүй. Харин махбод дахь Бурханы ажил асар өөр байдаг: Үүнд үгийн нарийн зөв удирдамж байдаг ба тодорхой хүсэл, тодорхой шаардсан зорилготой байдаг. Иймээс хүн тэмтчин бэдэрч, төсөөллөө ашиглах хэрэггүй, таамаглал дэвшүүлэх бүр ч хэрэггүй. Энэ бол махбод дахь ажлын тодорхой байдал бөгөөд Сүнсний ажлаас ялгагдах асар том ялгаа юм. Сүнсний ажил хязгаарлагдмал цар хүрээнд л тохиромжтой бөгөөд махбодын ажлыг орлож чадахгүй. Махбодын ажил нь Сүнсний ажлаас хавьгүй илүү үнэн зөв, чухал шаардлагатай зорилго болон хавьгүй илүү бодит, үнэ цэнтэй мэдлэгийг хүнд өгдөг. Завхарсан хүний хувьд үнэн зөв үгс, эрэлхийлэх тодорхой зорилго болон харж, хүрч болох ажил л хамгийн үнэ цэнтэй юм. Бодитой ажил, цагаа олсон удирдамж л хүний дур сонирхолд таарч тохирдог бөгөөд бодит ажил л хүнийг завхарсан, доройтсон зан чанараас нь аварч чадна. Үүнийг бие махбодтой болсон Бурхан л биелүүлж чадна; бие махбодтой болсон Бурхан л хүнийг урьдын завхарсан, доройтсон зан чанараас нь аварч чадна. Сүнс бол Бурханы төрөлх мөн чанар хэдий ч иймэрхүү ажлыг зөвхөн Түүний махбод л хийж чадна. Хэрвээ Сүнс дангаараа ажилласан бол Түүний ажил ур дүнтэй байх боломжгүй байсан—энэ бол илэрхий үнэн юм. Энэхүү махбодоос болж ихэнх хүн Бурханы дайсан болсон ч гэсэн Түүнийг ажлаа дуусгах үед Түүний эсрэг байдаг хүмүүс дайснууд нь байхаа болиод зогсохгүй, харин ч эсрэгээрээ Түүний гэрчлэгчид болно. Тэд Түүгээр байлдан дагуулагдсан, Түүнтэй нийцэлтэй, Түүнээс салшгүй гэрчлэгчид болно. Тэрээр, махбод дахь ажлынхаа ач холбогдлыг хүнд мэдүүлэх ба хүний оршин тогтнол дахь энэ махбодын ач холбогдол, хүний амийн өсөлтөн дэх Түүний бодит үнэ цэнийг хүн мэдэх болно, түүнчлэн энэ махбод бол

хүний салж үл түвдэх амийн амьд булаг болно гэдгийг ч мэднэ. Хэдийгээр Бурханы махбод болсон бие нь Бурханы ялгамж чанар, байр сууринд нийцэхэд хол, мөн Түүний бодит байр суурьтай нийцэхгүй мэт хүнд санагдавч Бурханы жинхэнэ дүр төрхгүй, эсвэл Бурханы жинхэнэ ялгамж чанаргүй энэ махбод нь Бурханы Сүнсний шууд хийж чадахгүй ажлыг хийж чадна. Энэ бол бие махбодтой болсон Бурханы жинхэнэ ач холбогдол, үнэ цэн бөгөөд энэхүү ач холбогдол, үнэ цэнийг хүн ойлгож, хүлээн зөвшөөрч чаддаггүй. Бүх хүн төрөлхтөн Бурханы Сүнсийг дээдэлж, Бурханы махбодыг дорд үздэг хэдий ч тэдний хэрхэн харж, боддогоос үл хамааран махбодын бодит ач холбогдол болон үнэ цэн нь Сүнснийхээс хавьгүй хол давдаг. Мэдээж завхарсан хүн төрөлхтний хувьд л ийм байдаг. Үнэнийг эрж хайдаг, Бурханы илрэлтийг хүсэн хүлээдэг хүн бүрийн хувьд Сүнсний ажил нь зөвхөн сэтгэл хөдөлгөж, онгодоор хангаж, тайлбарлашгүй, төсөөлшгүй гайхалтай байдлын мэдрэмж, мөн агуу, ер бусын, бишрэм атлаа бүх хүний олж авч, хүрч чадахааргүй мэдрэмжийг л өгдөг. Хүн, Бурханы Сүнс хоёрын хооронд асар их зай байгаа мэт, тэд хэзээ ч адилхан байж чадахгүй мэт, хүн Бурхан хоёрыг үл үзэгдэх заагаар тусгаарласан мэт алсаас л бие биеэ харж чадна. Үнэндээ, Сүнс хүн хоёр нэг төрлийн зүйл биш, нэг ертөнцөд хамт хэзээ ч оршихгүй, Сүнсэнд хүний гэх юу ч байдаггүй учраас энэ нь хүнд Сүнсний өгсөн төөрөгдөл юм. Иймээс хүнд хамгийн их хэрэгтэй ажлыг Сүнс шууд хийж чаддаггүй учраас хүнд Сүнс хэрэггүй. Махбодын ажил нь хүнд эрэлхийлэх бодит зорилго, тодорхой үгсийг болон Тэр бол бодитой агаад хэвийн, эгэл жирийн агаад даруухан гэх мэдрэмжийг өгдөг. Хэдий хүн Түүнээс айдаг байж болох ч ихэнх хүмүүсийн хувьд Тэр харилцахад тун хялбар байдаг: Хүн Түүний царайг харж, дуу хоолойг нь сонсож чадах ба Түүнийг алсаас харах шаардлагагүй. Энэхүү махбод нь хүнтэй адил нэг ертөнцөд оршдог учраас хүний хувьд хүрч болохуйц санагддаг бөгөөд хол юм уу ойлгошгүй биш, харин ч харж, хүрч болохуйц байдаг.

Махан биед амьдардаг бүх хүний хувьд зан чанараа өөрчлөхөд эрэлхийлэх зорилго шаардлагатай байдаг бөгөөд Бурханыг мэдэхэд Бурханы бодит үйл хэрэг болон жинхэнэ нүүр царайг харах шаардлагатай байдаг. Хоёуланд нь Бурханы махбод болсон бие л хүрч чадах ба хоёуланг нь хэвийн, бодитой махбодоор л биелүүлж чадна. Ийм учраас бие махбодтой болох шаардлагатай бөгөөд энэ нь завхарсан бүх хүн төрөлхтөнд хэрэгтэй. Хүмүүс Бурханыг мэдэх шаардлагатай учраас тодорхойгүй, ер бусын бурхдын дүр төрхийг зүрх сэтгэлээс нь зайлуулах ёстой, хүмүүс завхарсан зан чанараасаа салах шаардлагатай учраас тэд эхлээд завхарсан зан чанараа мэдэх ёстой. Хэрвээ хүмүүсийн зүрх сэтгэлээс тодорхойгүй бурхдын дүр төрхийг зайлуулах тэр ажлыг зөвхөн хүн хийвэл зохих үр дүнд хүрч чадахгүй. Хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа тодорхойгүй бурхдын дүр төрхийг дан ганц үгээр ил болгож, хаяж, бүрэн зайлуулж чадахгүй. Хэрвээ ингэвэл эцэстээ эдгээр гүн үндэслэсэн зүйлийг хүмүүсээс зайлуулах боломжгүй хэвээр байх болно. Эдгээр тодорхойгүй, ер бусын зүйлсийг бодитой Бурхан болон Бурханы жинхэнэ

дүрээр орлуулж, хүмүүст тэдгээрийг аажмаар мэдүүлснээр л зохих үр дүнд хүрч чадна. Өнгөрсөн хугацаанд эрж хайж байсан Бурхан нь тодорхойгүй, ер бусын гэдгийг хүн танин мэддэг. Энэ үр дүнд, Сүнсний шууд удирдлага биш, хэн нэгэн хүний сургаал бүр ч биш, харин бие махбодтой болсон Бурхан л хүрч чадна. Бие махбодтой болсон Бурханы хэвийн ба бодит байдал нь хүний төсөөлөлд байгаа тодорхойгүй, ер бусын Бурханы эсрэг байдаг учраас бие махбодтой болсон Бурханыг албан ёсоор Өөрийн ажлыг хийх үед хүний үзэл бүгд ил болдог. Бие махбодтой болсон Бурхантай сөргүүлэн тавьснаар л хүний анхдагч үзлийг илчлэх боломжтой. Бие махбодтой болсон Бурхантай харьцуулахгүйгээр хүний үзэл илчлэгдэх боломжгүй; өөрөөр хэлбэл, бодит байдалтай зэрэгцүүлэн тавихгүйгээр тодорхойгүй зүйлс илчлэгдэх боломжгүй. Хэн ч үг ашиглан энэ ажлыг хийж чадахгүй, хэн ч үгээр энэ ажлыг тодорхой илэрхийлж чадахгүй. Бурхан Өөрөө л Өөрийнхөө ажлыг хийж чадахаас биш, Түүний өмнөөс өөр хэн ч энэ ажлыг хийж чадахгүй. Хүний хэл хэр баялаг байх нь хамаагүй, хүн Бурханы бодитой болон хэвийн байдлыг тодорхой илэрхийлэх чадваргүй. Бурхан хүмүүсийн дунд биечлэн ажиллаж, Өөрийнхөө дүр болон оршихуйг бүрэн харуулах л юм бол хүн Бурханыг илүү бодитоор мэдэж, Түүнийг илүү тодорхой харж чадна. Энэ үр дүнд махан биетэй ямар ч хүн хүрч чадахгүй. Мэдээж Бурханы Сүнс ч бас энэ үр дүнд хүрэх чадваргүй. Бурхан завхарсан хүнийг Сатаны нөлөөнөөс аварч чадна, гэхдээ энэ ажлыг Бурханы Сүнс шууд биелүүлж чадахгүй; харин үүнийг Бурханы Сүнсний өмсдөг махбод буюу Бурханы махбод болсон бие л хийж чадна. Энэ махбод нь хүн бас Бурхан, хэвийн хүн чанартай хүн, бас бүрэн бурханлаг чанартай Бурхан юм. Иймээс, энэ махбод хэдийгээр Бурханы Сүнс биш бөгөөд Сүнснээс асар их ялгаатай ч тэр бол хүнийг авардаг бие махбодтой болсон Бурхан Өөрөө буюу Сүнс, түүнчлэн махбод билээ. Түүнийг юу гэж нэрлэх нь хамаагүй, эцсийн эцэст Бурхан Өөрөө хүн төрөлхтнийг авардаг. Учир нь Бурханы Сүнсийг махбодоос салгашгүй бөгөөд махбодын ажил ч бас Бурханы Сүнсний ажил юм; зүгээр л энэ ажлыг Сүнсний ялгамж чанараар хийдэггүй, харин махбодын ялгамж чанараар хийдэг. Сүнсээр шууд хийх хэрэгтэй ажил нь бие махбодтой болохыг шаарддаггүй бөгөөд махбодоор хийх шаардлагатай ажлыг Сүнсээр шууд хийж болохгүй, үүнийг бие махбодтой болсон Бурхан л хийж чадна. Энэ нь энхүү ажилд шаардагддаг зүйл бөгөөд завхарсан хүн төрөлхтний шаарддаг зүйл юм. Бурханы ажлын гурван үе шатанд зөвхөн нэг үе шатыг л Сүнс шууд хийсэн ба үлдсэн хоёр үе шатыг Сүнс биш, харин бие махбодтой болсон Бурхан хийсэн. Сүнсний хийсэн Хуулийн эрин үеийн ажил нь хүний завхарсан зан чанарыг өөрчлөхтэй хамаагүй, Бурханы талаарх хүний мэдлэгтэй ч хамаагүй байсан. Нигүүлслийн эрин үе ба Хаанчлалын эрин үе дэх Бурханы махбодын ажил нь харин хүний завхарсан зан чанар болон Бурханы талаарх түүний мэдлэгтэй хамаатай бөгөөд авралын ажлын чухал, шийдвэрлэх хэсэг юм. Тиймээс завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон Бурханы аврал илүү их хэрэгтэй, бие махбодтой болсон Бурханы шууд ажил илүү

хэрэгтэй байдаг. Хүн төрөлхтөнд өөрсдийг нь хариулах, дэмжих, услах, тэжээх, шүүх, гэсгээх бие махбодтой болсон Бурхан хэрэгтэй бөгөөд бие махбодтой болсон Бурханы илүү их нигүүлсэл, илүү агуу золин аврал хэрэгтэй. Махбод дахь Бурхан л хүний дотнын нэгэн, хүний хоньчин, байнгын туслагч байж чадах бөгөөд энэ бүхэн нь өнөөдөр болон өнгөрсөн үед бие махбодтой болсны хэрэгцээ шаардлага билээ.

Хүн Сатаны завхралд өртсөн, Бурханы бүх бүтээлийн хамгийн дээд нь юм, иймээс ч хүнд Бурханы аврал хэрэгтэй. Бурханы авралын бай бол Сатан биш, харин хүн, аврагдах зүйл бол диавол биш, харин хүний махан бие болон сүнс юм. Сатан бол Бурханы устгах бай, хүн бол Бурханы авралын бай бөгөөд хүний махан биеийг Сатан завхруулсан болохоор эхлээд хүний махан бие аврагдах ёстой. Хүний махан бие нь хамгийн гүн гүнзгий завхарч, Бурханыг эсэргүүцдэг, тэр ч байтугай Бурханы оршин тогтнолыг ил тод эсэргүүцэж, үгүйсгэдэг зүйл болсон. Энэ завхарсан махан бие дэндүү зөрүүд бөгөөд махан биеийн завхарсан зан чанартай харьцаж, өөрчлөхөөс илүү хэцүү зүйл гэж үгүй. Сатан хүний махан биед ирж үймүүлдэг ба Бурханы ажилд саад болж, Бурханы төлөвлөгөөг сүйтгэхийн тулд хүний махан биеийг ашигладаг, тиймээс хүн Бурханы дайсан, Сатан болсон юм. Хүнийг аврахын тулд эхлээд байлдан дагуулах ёстой. Үүнээс болж Бурхан мөчөөгөө өгөлгүйгээр, зорьсон ажлаа хийхээр, Сатантай тулалдахаар махбодод ирдэг. Түүний зорилго бол завхарсан хүнийг аварч, Өөрийнх нь эсрэг тэрсэлсэн Сатаныг ялж, устгах явдал юм. Хүнийг байлдан дагуулах ажлаараа дамжуулан Тэрээр Сатаныг ялахын зэрэгцээ завхарсан хүн төрөлхтнийг авардаг. Тиймээс энэ нь хоёр зорилгод нэгэн зэрэг хүрдэг ажил юм. Тэр хүнтэй илүү сайн харилцаж, хүнийг илүү сайн байлдан дагуулахын тулд махбодоор ажиллаж, үг хэлж, бүх ажлаа хийдэг. Бурхан сүүлчийн удаа бие махбод болж, Түүний эцсийн өдрүүдийн ажил махбодоор гүйцэлдэнэ. Тэрээр бүх хүнийг төрлийнх нь дагуу ангилж, Өөрийн бүх удирдлагыг дуусгаж, мөн махбод дахь бүх ажлаа дуусгана. Газар дээрх бүх ажил нь дуусгавар болоход Тэр бүрэн ялсан байх болно. Махбодод ажиллаж байх үедээ Бурхан хүн төрөлхтнийг бүрэн байлдан дагуулж, бүрэн олж авсан байх болно. Энэ нь Түүний бүх удирдлага дуусгавар болно гэсэн үг бус уу? Бурхан махбод дахь ажлаа дуусган, Сатаныг бүрэн ялж, ялалтаа мандуулах үед хүнийг завхруулах боломж Сатанд дахин олдохгүй. Эхний удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь хүнийг нүглээс золин аварч, уучлах явдал байсан. Одоо энэ нь хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүрэн олж авах ажил юм, ингэснээр Сатан цаашид өөрийн ажлыг хийх аргагүй болж, бүрмөсөн ялагдаж, Бурхан бүрэн ялсан байх болно. Энэ бол махбодын ажил, мөн Бурханы Өөрийн хийдэг ажил юм. Бурханы ажлын гурван үе шатны эхний ажлыг махбод биш, Сүнс шууд хийсэн. Харин Бурханы ажлын гурван үе шатны сүүлчийн ажлыг Сүнс шууд хийдэггүй, бие махбодтой болсон Бурхан хийдэг. Дундах үе шатны золин авралын ажлыг ч бас махбод дахь Бурхан хийсэн. Бүхий л удирдлагын ажлаас хамгийн чухал ажил нь хүнийг Сатаны нөлөөнөөс аврах явдал юм. Гол ажил нь завхарсан хүнийг бүрэн

байлдан дагуулж, улмаар байлдан дагуулагдсан хүний Бурханыг хүндлэх анхдагч зүрх сэтгэлийг нь сэргээж, хэвийн хүний амьдрал буюу Бурханы бүтээлийн хэвийн амьдралтай болгох явдал юм. Энэ ажил чухал бөгөөд удирдлагын ажлын цөм нь билээ. Авралын ажлын гурван үе шатанд, ажлын эхний үе шат болох Хуулийн эрин үе нь удирдлагын ажлын цөмөөс хол байсан; үүнд авралын ажил өчүүхэн төдий үзэгдэж байсан ба энэ нь Сатаны эзэмшлээс хүнийг аврах Бурханы ажлын эхлэл байгаагүй. Хуулийн дор хүн зөвхөн хуулийг мөрдөхөө л мэддэг байсан ба хүнд илүү их үнэн байгаагүй, мөн Хуулийн эрин үе дэх ажил хүний зан чанарыг өөрчлөхтэй бараг хамаагүй, Сатаны эзэмшлээс хүнийг хэрхэн аврах тухай ажилтай бүр ч холбоогүй байсан учраас ажлын эхний үе шатыг Сүнс шууд хийжээ. Тиймээс хүний завхарсан зан чанартай хамаагүй туйлын энгийн ажлын энэ үе шатыг Бурханы Сүнс гүйцэтгэсэн юм. Ажлын энэ үе шат удирдлагын цөмтэй өчүүхэн холбоотой бөгөөд хүнийг аврах албан ёсны ажилтай тийм ч их уялдаа холбоогүй байсан тул ажлаа биечлэн хийхийн тулд Бурхан махбод болох шаардлагагүй байлаа. Сүнсний хийсэн ажил далд утгатай, ойлгошгүй, хүний хувьд ихэд айдас төрүүлэм, ойртохын аргагүй байдаг; Сүнс нь авралын ажлыг шууд хийхэд тохиромжгүй, хүнийг амиар шууд хангахад тохиромжгүй байдаг. Хүний хувьд хамгийн тохиромжтой нь Сүнсний ажлыг хүнд ойр арга зам болгон өөрчлөх явдал бөгөөд өөрөөр хэлбэл, Өөрийн ажлыг хийхийн тулд Бурхан эгэл жирийн, хэвийн хүн болох нь хүнд хамгийн тохиромжтой. Сүнсний ажлыг орлохын тулд Бурхан бие махбодтой болохыг энэ нь шаарддаг бөгөөд хүний хувьд үүнээс илүү тохиромжтой арга гэж үгүй. Ажлын энэ гурван үе шатны дундаас хоёр үе шатыг махбодоор гүйцэтгэдэг ба энэ хоёр үе шат нь удирдлагын ажлын гол шат юм. Хоёр удаа бие махбодтой болсон нь харилцан бие биеэ нөхөж, нэг нэгнээ иж бүрэн болгодог. Бурхан бие махбодтой болсон эхний үе шат нь хоёр дахь үе шатны суурийг тавьсан, мөн Бурхан хоёр удаа бие махбодтой болсон нь нэгэн бүхэл болдог ба өөр хоорондоо нийцэлтэй байдаг гэж хэлж болно. Бурханы ажлын энэ хоёр үе шат нь бүхий л удирдлагын ажилд нэн чухал учраас Бурхан үүнийг Өөрийн махбодын ялгамж чанараар гүйцэтгэдэг. Хоёр удаа бие махбодтой болсон Бурханы ажилгүйгээр удирдлагын бүхий л ажил зогсож, хүн төрөлхтнийг аврах ажил хоосон ярианаас цаашгүй болох байсан гэж хэлж бараг болно. Энэ ажил чухал эсэх нь хүн төрөлхтний хэрэгцээ, хүн төрөлхтний доройтлын бодит байдал, Сатаны дуулгаваргүй байдлын хэмжээ болон ажилд саад хийж байгаа байдалд нь үндэслэдэг. Даалгаварт тохирох зөв нэгнийг, ажилчны гүйцэтгэсэн ажлын шинж чанар болон чухал байдалд үндэслэн тогтоодог. Энэ ажлын чухал байдлын тухайд бол ажлын ямар арга барил ашиглахтай хамаатайгаар—Бурханы Сүнсний шууд хийдэг ажил, эсвэл бие махбодтой болсон Бурханы хийдэг ажил, эсвэл хүнээр дамжин хийгддэг ажил—энэ гурвын дундаас эхлээд таягдан хаягдах зүйл бол хүнээр дамжин хийгддэг ажил бөгөөд ажлын шинж чанарт үндэслэн, Сүнсний ажлын шинж чанарыг махбодынхтой харьцуулан харвал махбодоор хийгддэг ажил нь Сүнсээр шууд хийгддэг ажлыг бодвол хүнд илүү их ач

тустай байж, илүү их давуу тал олгодог гэдгийг эцэст нь тодорхойлж болно. Ажлыг махбодоор хийх үү, эсвэл Сүнсээр хийх үү гэдэг нь тухайн үеийн Бурханы бодлоор шийдэгддэг. Ажлын үе шат бүрд ач холбогдол, үндэслэл бий. Тэдгээр нь үндэслэлгүй төсөөлөл биш, мөн тэдгээрийг дураараа гүйцэтгэдэг ч юм биш; тэдгээрт тодорхой мэргэн ухаан бий. Энэ бол Бурханы ажлын ард буй үнэн юм. Ялангуяа бие махбодтой болсон Бурхан хүмүүсийн дунд биечлэн ажиллах ийм агуу ажилд Бурханы төлөвлөгөө бүр ч их байдаг. Иймээс Бурханы мэргэн ухаан болон Түүний оршихуй бүхэлдээ, ажиллаж байх үеийнх нь үйлдэл, бодол, санаа бүрд тусгалаа олдог; энэ бол илүү бодит, системтэй Бурханы оршихуй юм. Эдгээр нарийн бодол санааг төсөөлж, итгэхэд, тэр ч бүү хэл мэдэхэд хүний хувьд хэцүү байдаг. Хүний хийсэн ажил нь ерөнхий зарчмын дагуу хийгддэг ба хүний хувьд тун сэтгэл ханамжтай байдаг. Гэсэн ч Бурханы ажилтай харьцуулахад ердөө дэндүү их ялгаа бий; хэдийгээр Бурханы үйл хэрэг агуу, Бурханы ажил өргөн цар хүрээтэй боловч тэдгээрийн ард хүний төсөөлж чадахааргүй олон нарийн, нягт нямбай төлөвлөгөө, зохицуулалт байдаг. Түүний ажлын үе шат бүр зарчмын дагуу явагддагаар зогсохгүй, хүний хэлээр тодорхой илэрхийлэх боломжгүй олон зүйлийг агуулдаг бөгөөд эдгээр нь хүнд үл үзэгдэх зүйлс юм. Сүнсний ажил, эсвэл бие махбодтой болсон Бурханы ажил байх нь хамаагүй, тус бүрдээ Түүний ажлын төлөвлөгөөг агуулж байдаг. Тэр ул суурьгүй ажилладаггүй, бас ач холбогдолгүй ажил хийдэггүй. Сүнс шууд ажиллах үедээ Өөрийн гэсэн зорилготой байдаг бөгөөд ажиллахын тулд хүн болох үедээ (өөрөөр хэлбэл, гадаад бүрхүүлээ өөрчлөх үедээ) бүр ч зорилготой байдаг. Өөр яах гэж Тэр Өөрийн ялгамж чанарыг дуртайяа өөрчлөх юм бэ? Өөр яах гэж Тэр дуртайяа дорд үзэгдэж, хавчигдах хүн болох юм бэ?

Ажил гэдэг үүднээс яривал махбод дахь Түүний ажил туйлын ач холбогдолтой бөгөөд ажлыг бүрэн дуусгадаг Нэгэн бол Сүнс биш, бие махбодтой болсон Бурхан билээ. Бурхан хэзээ нэг цагт газар дэлхий дээр ирж, хүмүүст харагдаж, улмаар бүх хүн төрөлхтнийг биечлэн шүүж, хэнийг нь ч үлдээлгүй нэг нэгээр нь туршиж магадгүй гэж зарим хүн итгэдэг. Ингэж боддог хүмүүс бие махбодтой болох ажлын энэ үе шатыг мэддэггүй. Бурхан хүмүүсийг нэг нэгээр нь шүүдэггүй ба нэг нэгээр нь туршдаггүй; ийнхүү хийвэл шүүлтийн ажил биш. Бүх хүн төрөлхтний завхрал адилхан бус уу? Бүх хүн төрөлхтний мөн чанар ижилхэн бус уу? Шүүгддэг зүйл нь хүн төрөлхтний завхарсан мөн чанар, Сатаны завхруулсан хүний мөн чанар, хүний бүх нүгэл билээ. Хүний ялихгүй, аар саар алдааг Бурхан шүүдэггүй. Шүүлтийн ажил бэлгэдлийн чанартай бөгөөд ялангуяа тодорхой нэг хүнд зориулж хийгддэггүй. Харин ч энэ нь, бүх хүн төрөлхтнийг шүүх ажлыг төлөөлөхийн тулд бүлэг хүмүүсийг шүүдэг ажил юм. Бүлэг хүмүүс дээр Өөрийн ажлыг биечлэн гүйцэтгэснээр махбод дахь Бурхан, бүх хүн төрөлхтний ажлыг төлөөлүүлэхийн тулд Өөрийг ажлыг ашигладаг ба үүний дараа энэ нь аажмаар тархдаг. Шүүлтийн ажил ч гэсэн ийм байдаг. Бурхан тодорхой нэг төрлийн хүн, эсвэл тодорхой бүлэг хүмүүсийг шүүдэггүй, харин бүх хүн төрөлхтний зөвт бус байдал буюу тухайлбал, Бурханд

хандах хүний эсэргүүцэл, Бурханыг хүндэлдэггүй байдал, эсвэл Бурханы ажлыг үймүүлдэг байдал зэргийг шүүдэг. Шүүгддэг зүйл нь хүн төрөлхтний Бурханыг эсэргүүцдэг мөн чанар бөгөөд энэ ажил нь эцсийн өдрүүдийн байлдан дагуулалтын ажил юм. Хүний харсан бие махбодтой болсон Бурханы ажил болон үг нь өнгөрсөн хугацаанд хүмүүсийн бодож төсөөлж ирсэн эцсийн өдрүүд дэх агуу цагаан сэнтийн өмнөх шүүлтийн ажил билээ. Бие махбодтой болсон Бурханы одоо хийж буй ажил нь чухамдаа агуу цагаан сэнтийн өмнөх шүүлт юм. Өнөөдрийн бие махбодтой болсон Бурхан бол эцсийн өдрүүдэд бүх хүн төрөлхтнийг шүүдэг Бурхан мөн. Энэ махбод болон Түүний ажил, үг, бүхий л зан чанар нь Тэр бүхэлдээ билээ. Хэдийгээр Түүний ажлын цар хүрээ хязгаарлагдмал, бүх орчлон ертөнцийг шууд хамардаггүй ч шүүлтийн ажлын мөн чанар нь бүх хүн төрөлхтнийг шууд шүүх шүүлт юм—энэ нь зөвхөн Хятадын сонгогдсон хүмүүсийн төлөө байдаггүй, цөөн тооны хүмүүсийн төлөө ч байдаггүй. Махбод дахь Бурханы ажлын үеэр, энэ ажлын цар хүрээ нь хэдийгээр бүх орчлон ертөнцийг хамардаггүй ч бүх орчлон ертөнцийн ажлыг төлөөлдөг бөгөөд Өөрийн махбодын ажлын цар хүрээн дэх ажлыг дуусгасныхаа дараа Тэрээр, Есүсийг амилж, тэнгэр өөд гарсны дараа сайн мэдээ нь бүх орчлон ертөнц даяар тархсантай адилаар энэхүү ажлыг бүх орчлон ертөнцөд нэн даруй өргөжүүлнэ. Сүнсний ажил, эсвэл махбодын ажлын аль нь ч бай, хязгаарлагдмал цар хүрээнд хийгддэг ажил боловч бүх орчлон ертөнцийн ажлыг төлөөлдөг. Эцсийн өдрүүдэд Бурхан, Өөрийн бие махбодын ялгамж чанараар гарч ирж ажлаа хийдэг ба махбод дахь Бурхан бол агуу цагаан сэнтийн өмнө хүнийг шүүдэг Бурхан юм. Сүнс юм уу махбод байх нь хамаагүй, шүүлтийн ажлыг хийгч нь эцсийн өдрүүдэд хүн төрөлхтнийг шүүдэг Бурхан билээ. Энэ нь Түүний ажилд үндэслэн тодорхойлогддог ба Түүний гадаад төрх байдал болон өөр хэд хэдэн хүчин зүйлийн дагуу тодорхойлогддоггүй. Хэдийгээр хүн эдгээр үгийн талаар үзэл өвөрлөдөг ч бие махбодтой болсон Бурхан бүх хүн төрөлхтнийг шүүж, байлдан дагуулдаг бодит баримтыг хэн ч үгүйсгэж чадахгүй. Хүн энэ талаар юу гэж бодох нь хамаагүй, эцсийн эцэст баримт бол баримт. “Ажлыг Бурхан хийдэг боловч махбод бол Бурхан биш” гэж хэн ч хэлж чадахгүй. Энэ нь утгагүй, учир нь энэ ажлыг махбод дахь Бурханаас өөр хэн ч хийж чадахгүй. Энэ ажил хэдийнээ дууссан тул энэ ажлын дараа хүнийг шүүх Бурханы шүүлтийн ажил хоёр дахь удаагаа гарч ирэхгүй; хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурхан бүхий л удирдлагын ажлыг аль хэдийн гүйцэлдүүлсэн бөгөөд Бурханы ажлын дөрөв дэх үе шат гэж байхгүй. Шүүгддэг нэгэн нь махан биеэс бүтсэн, завхарсан хүн болохоос Сатаны сүнс шууд шүүгддэггүй учраас шүүлтийн ажил нь сүнсний ертөнцөд биш, харин хүмүүсийн дунд хийгддэг. Хүний махан биеийн завхралыг шүүх ажилд махбод дахь Бурханаас илүү таарч, тохирох өөр хэн ч байхгүй. Хэрэв шүүлтийг Бурханы Сүнс шууд явуулсан бол бүгдийг хамрахгүй байх байв. Түүнчлэн Сүнс хүнтэй нүүр тулан уулзаж чадахгүй учраас ийм ажлыг хүлээн зөвшөөрөх нь хүний хувьд хэцүү байх байсан ба үүнээс болоод үр дүн нь тэр даруй харагдахгүй, тэр ч бүү хэл Бурханы

халдашгүй зан чанарыг хүн илүү тодорхой харж чадахгүй байх байлаа. Махбод дахь Бурхан хүн төрөлхтний завхралыг шүүсэн цагт л Сатаныг бүрэн ялж болно. Хэвийн хүн чанар эзэмшдэг хүнтэй адил байснаар махбод дахь Бурхан хүний зөвт бус байдлыг шууд шүүж чаддаг; энэ бол Түүний төрөлхийн ариун байдал болон Түүний ер бусын байдлын тэмдэг юм. Бурхан л хүнийг шүүх байр суурьтай байж, хүнийг шүүхэд тохирно, учир нь Тэр үнэн болон зөвт байдлыг эзэмшдэг тул хүнийг шүүх чадвартай. Үнэн болон зөвт байдалгүй хүмүүс бусдыг шүүхэд тохирохгүй. Хэрвээ энэ ажлыг Бурханы Сүнс хийсэн бол Сатаныг ялах ялалт биш байх байлаа. Сүнс төрөлхөөсөө мөнх бус хүмүүсээс илүү өндөр дээд бөгөөд Бурханы Сүнс бол төрөлхийн ариун, махан биеэс илүү ялгуусан. Хэрвээ Сүнс энэ ажлыг шууд хийсэн бол хүний бүх дуулгаваргүй байдлыг шүүж, хүний бүх зөвт бус байдлыг илчилж чадахгүй байх байсан юм. Учир нь шүүлтийн ажлыг бас Бурханы талаарх хүний үзлээр дамжуулан хийдэг ба хүнд хэзээ ч Сүнсний талаарх үзэл байгаагүй, иймээс Сүнс хүний зөвт бус байдлыг сайн илчилж чадахгүй, ийм зөвт бус байдлыг бүрэн ил болгож бүр ч чадахгүй. Бие махбодтой болсон Бурхан бол Өөрийг нь мэддэггүй бүх хүний дайсан юм. Хүний үзэл болон Бурханыг эсэргүүцэх эсэргүүцлийг шүүснээр Тэр хүн төрөлхтний бүх дуулгаваргүй байдлыг ил болгодог. Махбод дахь Түүний ажлын үр дүн нь Сүнсний ажлынхаас илүү илэрхий байдаг. Иймээс бүх хүн төрөлхтнийг шүүх шүүлтийг Сүнс шууд явуулдаггүй, харин энэ нь бие махбодтой болсон Бурханы ажил юм. Махбод дахь Бурханыг хүн харж, хүрч болох ба махбод дахь Бурхан хүнийг бүрэн байлдан дагуулж чадна. Махбод дахь Бурхантай харилцахдаа хүн эсэргүүцлээс дуулгавартай байдал руу, хавчлагаас хүлээн зөвшөөрөл рүү, үзлээс мэдлэг рүү, гололтоос хайр луу хөгжин дэвшдэг—эдгээр нь бие махбодтой болсон Бурханы ажлын үр дүн юм. Түүний шүүлтийг хүлээн зөвшөөрснөөр л хүн аврагдаж, амнаас нь гарсан үгээр дамжуулан Түүнийг аажмаар мэдэж авч, Түүнийг эсэргүүцэх явцдаа Түүгээр байлдан дагуулагдаж, гэсгээлтийг нь хүлээн зөвшөөрснөөр амийн хангалтыг Түүнээс хүртдэг. Энэ бүх ажил нь махбод дахь Бурханы ажил бөгөөд Сүнсний ялгамж чанараар Бурханы хийсэн ажил биш. Бие махбодтой болсон Бурханы хийсэн ажил хамгийн агуу, хамгийн гүн гүнзгий ажил бөгөөд Бурханы ажлын гурван үе шатны шийдвэрлэх чухал хэсэг нь бие махбодтой болох ажлын хоёр үе шат билээ. Хүн гүн гүнзгий завхарсан учраас бие махбодтой болсон Бурханы ажилд асар их саад болдог. Ялангуяа эцсийн өдрүүдийн хүмүүс дээр хийгддэг ажил асар хэцүү, гаднын орчин муу бөгөөд төрөл бүрийн хүний хэв чанар тун дорд байдаг. Гэсэн ч энэ ажил дуусах үедээ ямар ч алдаа мадаггүйгээр, зохих үр дүнд хүрнэ; энэ бол махбодын ажлын үр дүн бөгөөд энэ үр дүн нь Сүнсний ажлынхаас илүү үнэмшилтэй. Бурханы ажлын гурван үе шат махбодоор гүйцэлдэх бөгөөд үүнийг бие махбодтой болсон Бурхан дуусгах ёстой. Хамгийн чухал, хамгийн шийдвэрлэх ажлыг махбодоор хийдэг бөгөөд хүнийг аврах ажлыг махбод дахь Бурхан биечлэн гүйцэтгэх ёстой. Хэдий бүх хүн төрөлхтөнд, махбод дахь Бурхан нь хүнтэй хамаагүй мэт санагддаг ч

үнэндээ энэ махбод нь бүх хүн төрөлхтний хувь заяа, оршин тогтнолтой холбоотой.

Бурханы ажлын үе шат бүр бүх хүн төрөлхтний төлөө хийгддэг бөгөөд бүх хүн төрөлхтөнд чиглэдэг. Хэдий энэ нь Түүний махбод дахь ажил боловч бүх хүн төрөлхтөнд чиглэдэг; Тэр бол бүх хүн төрөлхтний Бурхан бөгөөд бүх бүтээгдсэн болон бүтээгдээгүй зүйлийн Бурхан юм. Хэдийгээр махбод дахь Түүний ажил хязгаарлагдмал цар хүрээн дотор байдаг, мөн энэ ажлын бай хязгаарлагдмал ч гэсэн ажлаа хийхээр махбод болох бүрдээ Тэр дээд зэргийн бэлгэдлийн чанартай ажлын байг сонгодог; Тэрээр энгийн, бусдаас ялгарах юмгүй бүлэг хүмүүс дээр ажиллахаар сонгодоггүй, харин махбод дахь ажлынх нь төлөөлөгч байж чадах бүлэг хүмүүсийг ажлынхаа бай болгон сонгодог. Махбод дахь Түүний ажлын цар хүрээ хязгаарлагдмал учраас энэ бүлэг хүмүүс сонгогддог бөгөөд Түүний махбод болсон биед зориулан тусгайлан бэлтгэгддэг, мөн махбодоор хийх Түүний ажилд зориулан тусгайлан сонгогддог. Бурхан Өөрийн ажлын байг сонгох нь үндэслэлгүй биш, харин зарчмын дагуу хийгддэг: Ажлын бай нь махбод дахь Бурханы ажилд ашиг тустай байж, бүх хүн төрөлхтнийг төлөөлж чаддаг байх ёстой. Тухайлбал иудейчүүд Есүсийн биечлэн хийсэн золин авралыг хүлээн авахдаа бүх хүн төрөлхтнийг төлөөлж чадсан бөгөөд бие махбодтой болсон Бурханы биечлэн хийдэг байлдан дагуулалтыг хүлээн авахдаа хятадууд бүх хүн төрөлхтнийг төлөөлж чаддаг. Иудейчүүд бүх хүн төрөлхтнийг төлөөлдөгт үндэслэл байдаг, хятад хүмүүс Бурханы биечлэн хийсэн байлдан дагуулалтыг хүлээн авахдаа бүх хүн төрөлхтнийг төлөөлдөгт мөн л үндэслэл бий. Золин авралын ач холбогдлыг иудейчүүдийн дунд хийгдсэн авралын ажлаас илүүгээр илчилж чадах өөр юу ч байхгүй, байлдан дагуулалтын ажлын бүрэн гүйцэд байдал болон амжилтыг хятадуудын дундах байлдан дагуулалтын ажлаас илүүгээр илчилж чадах юу ч байхгүй. Бие махбодтой болсон Бурханы ажил ба үг цөөхөн бүлэг хүмүүст л чиглэдэг мэт харагдавч үнэн хэрэгтээ Тэр энэ цөөхөн бүлэг хүмүүсийн дунд бүх орчлон ертөнцийн ажлыг хийж, бүх хүн төрөлхтөнд хандан үгээ хэлдэг. Махбод дахь Түүний ажил дууссаны дараа Түүнийг дагадаг хүмүүс өөрсдийнх нь дунд хийсэн Бурханы ажлыг түгээж эхэлнэ. Махбод дахь Түүний ажлын хамгийн сайн зүйл нь Тэр үнэн зөв үгс, захиас болон хүн төрөлхтний төлөөх тодорхой хүслээ Өөрийг нь дагадаг хүмүүст үлдээж чадна, ингэснээр Түүний дагалдагчид хожим нь махбод дахь Түүний бүх ажлыг болон бүх хүн төрөлхтний төлөөх Түүний хүслийг энэ замыг хүлээн зөвшөөрдөг хүмүүст илүү үнэн зөвөөр, илүү бодитоор дамжуулж чадна. Хүмүүсийн дундах махбод дахь Бурханы ажил л Бурхан хүнтэй хамт байж, хамт амьдардаг тухай баримтыг үнэхээр биелүүлдэг. Энэ ажил л Бурханы царайг харж, Бурханы ажлыг үзэж, Бурханы Өөрийн үгийг сонсох гэсэн хүний хүслийг биелүүлдэг. Бие махбодтой болсон Бурхан, Еховагийн нуруу л хүн төрөлхтөнд харагддаг эрин үеийг төгсгөдөг ба тодорхойгүй Бурханд итгэх хүн төрөлхтний итгэлийн эрин үеийг ч бас дуусгавар болгодог. Ялангуяа сүүлчийн удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь бүх хүн төрөлхтнийг илүү бодит, илүү жинхэнэ,

илүү сайхан эрин үед аваачдаг. Тэрээр хууль болон дүрэм журмын эрин үеийг дуусгавар болгоод зогсохгүй, илүү чухал нь, бодитой агаад хэвийн, зөвт агаад ариун, удирдлагын төлөвлөгөөний ажлыг нээж, хүн төрөлхтний нууц болон хүрэх газрыг харуулдаг, хүн төрөлхтнийг бүтээж, удирдлагын ажлыг дуусгавар болгодог, хэдэн мянган жилийн туршид нуугдмал байсан Бурханыг хүн төрөлхтөнд илчилдэг. Тэрээр тодорхойгүй байдлын эрин үеийг бүрэн дуусгавар болгож, бүх хүн төрөлхтөн Бурханы царайг харахаар эрж хайсан ч харж чаддаггүй байсан тэр эринийг дуусгаж, бүх хүн төрөлхтөн Сатанд үйлчилсэн эрин үеийг төгсгөж, бүх хүн төрөлхтнийг цоо шинэ эрин үе рүү хөтөлдөг. Энэ бүхэн нь Бурханы Сүнсний оронд махбод дахь Бурхан ажилласны үр дүн юм. Бурхан махбодоороо ажиллах үед Түүнийг дагадаг хүмүүс оршдог, бас эс оршдог мэт санагддаг тэдгээр зүйлийн хойноос хөөцөлдөн, тэмтчихээ больж, тодорхойгүй Бурханы хүслийг тааварлахаа больдог. Бурхан махбод дахь ажлаа түгээх үед Түүнийг дагадаг хүмүүс махбодоор хийсэн ажлыг нь бүх шашин, урсгалд дамжуулж, Түүний бүх үгийг бүх хүн төрөлхтний чихэнд хүргэнэ. Түүний сайн мэдээг хүлээн авдаг хүмүүсийн сонсдог бүхэн нь Түүний ажлын баримт байх болно, хүний биечлэн үзэж, сонссон зүйлс байх болно, мөн цуу яриа биш, баримт байх болно. Эдгээр баримт нь Түүний ажлаа түгээдэг нотолгоо, бас ажлаа түгээхдээ ашигладаг багаж хэрэгсэл билээ. Баримт байхгүй бол Түүний сайн мэдээ бүх улс орон, бүх газар нутаг даяар түгэхгүй байх байсан; баримт байхгүйгээр зөвхөн хүний төсөөллөөр бол Тэр бүх орчлон ертөнцийг байлдан дагуулах ажлыг хэзээ ч хийж чадахгүй байх байсан юм. Сүнс бол хүний хувьд мэдрэгдэшгүй, үзэгдэшгүй бөгөөд Сүнсний ажил нь Бурханы хийсэн ажлын талаарх ямар ч нэмэлт баримт, нотолгоог хүнд үлдээх чадваргүй. Хүн Бурханы бодит нүүр царайг хэзээ ч харахгүй ба оршин байдаггүй тодорхойгүй Бурханд үргэлж итгэнэ. Хүн Бурханы нүүр царайг хэзээ ч харахгүй, мөн Бурханы биечлэн хэлсэн үгийг хэзээ ч сонсохгүй. Хүний төсөөлөл эцсийн эцэст хоосон бөгөөд Бурханы жинхэнэ нүүр царайг орлож чадахгүй; Бурханы төрөлх зан чанар болон Бурханы Өөрийн ажлыг хүн дуурайж чадахгүй. Хүмүүсийн дунд Өөрийн ажлыг биечлэн хийдэг бие махбодтой болсон Бурхан л тэнгэр дэх үл үзэгдэх Бурхан болон Түүний ажлыг газар дээр авчирч чадна. Энэ бол Бурхан хүнд илрэн харагддаг, мөн хүн Бурханыг харж, Бурханы жинхэнэ нүүр царайг мэдэж авах хамгийн тохиромжтой арга бөгөөд үүнийг бие махбодтой болоогүй Бурхан биелүүлж чадахгүй. Энэ үе шатыг хүртэл ажлаа хийснээр Бурханы ажил аль хэдийн хамгийн сайн үр дүнд хүрч, бүрэн амжилттай болсон. Махбод дахь Бурханы биечлэн хийсэн ажил Түүний бүхий л удирдлагын ажлын ерэн хувийг аль хэдийн биелүүлсэн. Энэхүү махбод Өөрийнхөө бүх ажлыг илүү сайн эхлэл рүү аваачиж, Өөрийнхөө бүх ажилд дүгнэлт гаргаж, зарлан тунхагласан бөгөөд энэ бүх ажилд эцсийн иж бүрэн нэмэлтийг хийсэн. Тиймээс Бурханы ажлын дөрөв дэх үе шатыг хийх бие махбодтой болсон өөр Бурхан гэж байхгүй бөгөөд гурав дахь удаа бие махбодтой болсон Бурханы гайхалтай ажил гэж хэзээ ч байхгүй.

Махбод дахь Бурханы ажлын үе шат бүр бүхий л эрин үеийн ажлыг нь төлөөлдөг бөгөөд хүний ажилтай адилаар тодорхой нэг хугацааг төлөөлдөггүй. Иймээс сүүлчийн удаа бие махбодтой болсон Бурханы ажлын төгсгөл нь Түүний ажил бүрмөсөн төгсгөлдөө очсон гэсэн үг биш, учир нь махбод дахь Түүний ажил бүхий л эрин үеийг төлөөлдөг бөгөөд Өөрийн ажлыг махбодоор хийдэг үеийг нь зөвхөн төлөөлдөггүй. Бие махбодтой байх хугацаандаа Тэр бүхий л эрин үеийн ажлаа төгсгөдөг ба үүний дараа энэ нь бүх газар нутагт түгдэг. Бие махбодтой болсон Бурхан Өөрийн үйлчлэлийг биелүүлснийхээ дараа Өөрийг нь дагадаг хүмүүст ирээдүйн ажлаа даалгана. Ийм маягаар, бүхэл эрин үе дэх Түүний ажил тасалдалгүйгээр явагдана. Түүний ажил орчлон ертөнц даяар түгмэгц бие махбодтой болсон бүхий л эрин үеийн ажил бүрэн гүйцэлдсэн гэж тооцож болно. Бие махбодтой болсон Бурханы ажил шинэ эринийг эхлүүлдэг ба Түүний ажлыг үргэлжлүүлдэг хүмүүс бол Түүний ашигладаг хүмүүс юм. Хүний хийдэг ажил бүгд махбод дахь Бурханы үйлчлэл дотор байдаг бөгөөд энэ цар хүрээнээс хэтрэн гарах чадваргүй. Хэрвээ бие махбодтой болсон Бурхан Өөрийн ажлыг хийхээр ирээгүй бол хүн хуучин эрин үеийг дуусгаж, шинэ эрин үеийг эхлүүлж чадахгүй байх байлаа. Хүний хийдэг ажил ердөө л хүний хувьд хийх боломжтой үүргийнх нь хүрээнд байдаг бөгөөд Бурханы ажлыг төлөөлдөггүй. Бие махбодтой болсон Бурхан л ирж, хийх ёстой ажлаа гүйцээж чадна, Түүнээс өөр хэн ч Түүний өмнөөс энэ ажлыг хийж чадахгүй. Мэдээж Миний хэлж байгаа зүйл бие махбодтой болсны ажилтай холбоотой. Энэ удаа бие махбодтой болсон Бурхан эхлээд хүний үзэлтэй үл нийцэх ажлын алхмыг хийдэг, дараа нь Тэр хүний үзэлд нийцдэггүй илүү их ажлыг хийдэг. Ажлын зорилго нь хүнийг байлдан дагуулах явдал юм. Нэг талаараа бие махбодтой болсон Бурхан ердөө хүний үзэлтэй нийцдэггүйн дээр хүний үзэлтэй үл нийцэх илүү их ажил хийдэг тул хүн Түүний талаар илүү их шүүмжлэлт үзэл санаатай болдог. Харин Тэр ердөө л Түүний талаар тоо томшгүй олон үзэлтэй хүмүүсийн дунд байлдан дагуулах ажил хийдэг. Тэд Түүнд хэрхэн ханддагаас үл хамааран Түүнийг үйлчлэлээ биелүүлмэгц бүх хүн Түүний эрх мэдэлд захирагдана. Энэ ажлын баримт нь зөвхөн Хятад хүмүүсийн дунд тусгалаа олоод зогсохгүй, бас бүх хүн төрөлхтөн хэрхэн байлдан дагуулагдахыг төлөөлдөг. Энэ хүмүүс дээр хүрсэн үр дүн нь бүх хүн төрөлхтөн дээр биелэх үр дүнгийн анхдагч хэлбэр бөгөөд ирээдүйд Түүний хийх ажлын үр дүн нь эдгээр хүмүүст гарсан үр дүнгээс ч улам давна. Махбод дахь Бурханы ажил сүр дуулиантай байдаггүй, үл ойлгогдох зүйлсээр ч хүрээлэгддэггүй. Энэ нь үнэн бодит, мөн нэг дээр нэгийг нэмбэл хоёр гардаг шиг тов тодорхой ажил юм. Энэ нь хэнээс ч нуугдаж, хэнийг ч мэхэлдэггүй. Хүмүүсийн хардаг зүйлс бодит бөгөөд жинхэнэ зүйлс, хүний олж авдаг зүйлс ч бодит мэдлэг болон үнэн юм. Ажил дуусахад хүн Түүний талаар шинэ мэдлэгтэй болох ба үнэхээр эрэлхийлдэг хүмүүс Түүний талаар ямар нэгэн үзэлтэй байхаа болино. Энэ нь дан ганц хятад хүмүүс дээрх Түүний ажлын үр дүн биш, харин бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулах Түүний ажлын үр дүнг ч бас төлөөлдөг, учир нь

энэ махбод, энэ махбодын ажил болон энэ махбодын бүх зүйл бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулах ажилд хамгийн их ач тустай байдаг. Тэдгээр нь Түүний өнөөгийн ажилд тустай, мөн Түүний хожмын ажилд ч тустай. Энэ махбод бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүх хүн төрөлхтнийг олж авна. Бүх хүн төрөлхтөн Бурханыг харж, Бурханд дуулгавартай байж, Бурханыг мэдэх үүнээс илүү дээр ажил гэж үгүй. Хүний хийдэг ажил хязгаарлагдмал цар хүрээг л хамардаг бөгөөд Бурхан ажлаа хийх үедээ тодорхой нэг хүнтэй ярьдаггүй, харин бүх хүн төрөлхтөнтэй, Түүний үгийг хүлээн зөвшөөрдөг бүх хүнтэй ярьдаг. Түүний тунхагладаг төгсгөл бол тодорхой нэг хүний төгсгөл биш, харин бүх хүн төрөлхтний төгсгөл билээ. Тэр хэнийг ч тусгайлан харж ханддаггүй, мөн хэнийг ч хэлмэгдүүлдэггүй, Тэр бүх хүн төрөлхтний төлөө ажиллаж, үгээ хэлдэг. Тиймээс энэ удаа бие махбодтой болсон Бурхан бүх хүн төрөлхтнийг аль хэдийн төрлийнх нь дагуу ангилж, бүх хүн төрөлхтнийг аль хэдийн шүүж, бүх хүн төрөлхтөнд тохирох хүрэх газрыг зохицуулчихсан. Хэдий Бурхан зөвхөн Хятадад Өөрийн ажлыг хийж байгаа ч үнэндээ бүх орчлон ертөнцийн ажлыг аль хэдийн шийдвэрлэчихсэн. Тэрээр бүх хүн төрөлхтний дунд Өөрийнх нь ажил түгсний дараа Өөрийн айлдвар болон зохицуулалтыг алхам алхмаар хийхээр хүлээж тэвчихгүй. Тэгвэл хэт хожимдсон байх бус уу? Одоо Тэр хожмын ажлаа урьдчилан дуусгаж бүрэн чадна. Ажиллаж байгаа Нэгэн бол махбод дахь Бурхан учраас хязгаарлагдмал цар хүрээн дотор хязгааргүй ажил хийж байгаа, үүнийхээ дараа Тэр хүнээр өөрийнх нь үүргийг гүйцэтгүүлнэ; энэ бол Түүний ажлын зарчим юм. Тэр хүнтэй хамт хэсэгхэн зуур л амьдарч чадах бөгөөд бүх эрин үеийн ажил дуусах хүртэл хүнийг дагалдаж чадахгүй. Тэр Бурхан учраас Өөрийн хожмын ажлыг урьдчилан зөгнөдөг. Дараа нь Тэр Өөрийн үгээр бүх хүн төрөлхтнийг төрлийнх нь дагуу ангилж, хүн төрөлхтөн Түүний үгийн дагуу алхам алхмаар явагддаг ажилд нь орох болно. Хэн ч зугтан зайлж чадахгүй ба бүгд үүний дагуу хэрэгжүүлэх ёстой. Тиймээс ирээдүйд эрин үеийг Сүнс удирдахгүй, харин Түүний үг удирдана.

Махбод дахь Бурханы ажил махан биеэр хийгдэх ёстой. Хэрэв үүнийг Бурханы Сүнс шууд хийсэн бол ямар ч үр дүн гарахгүй. Үүнийг Сүнс хийсэн ч гэсэн тийм ч их ач холбогдолгүй, эцэстээ ямар ч үнэмшилгүй болох болно. Бүтээгчийн ажил ач холбогдолтой эсэх, юуг төлөөлдөг, юуны төлөө хийгддэг, Бурханы ажил эрх мэдэл, мэргэн ухаанаар дүүрэн эсэхийг болон хамгийн үнэ цэнтэй, ач холбогдолтой эсэхийг бүх бүтээл мэдэхийг хүсдэг. Түүний хийдэг ажил бүх хүн төрөлхтнийг аврахын төлөө, Сатаныг ялахын төлөө, мөн бүх зүйлийн дунд Түүнд гэрчлэл хийхийн төлөө байдаг. Иймээс Түүний хийдэг ажил асар их ач холбогдолтой байх ёстой. Хүний махан бие Сатанаар завхруулагдаж, хамгийн их сохорч, гүн гүнзгий хорлогдсон. Бурхан махбодоор биечлэн ажилладгийн хамгийн үндсэн шалтгаан нь, Түүний авралын бай махан биеэс бүтсэн хүн бөгөөд Бурханы ажилд саад хийхийн тулд Сатан ч бас хүний махан биеийг ашигладгаас болдог. Сатантай хийдэг тулаан нь үнэндээ хүнийг байлдан дагуулах ажил бөгөөд үүний зэрэгцээ хүн бас Бурханы авралын бай юм. Ийм болохоор бие махбодтой болсон Бурханы ажил тун чухал.

Сатан хүний махан биеийг завхруулж, хүн Сатаны биелэл болсон ба Бурханд ялагдах бай болсон юм. Ийм маягаар, Сатантай тулалдах, хүн төрөлхтнийг аврах ажил бүгд газар дэлхий дээр болдог бөгөөд Сатантай тулалдахын тулд Бурхан хүн болох ёстой байдаг. Энэ бол хамгийн бодитой ажил юм. Бурхан махбодоор ажиллах үедээ үнэндээ махан биеэр Сатантай тулалдаж байдаг. Тэр махбодоор ажиллах үедээ сүнсний ертөнцөд Өөрийн ажлыг хийж, сүнсний ертөнц дэх бүх ажлаа газар дээр бодит болгодог. Байлдан дагуулагддаг нэгэн нь Түүнд дуулгаваргүй байдаг хүн, харин ялагддаг нэгэн нь Түүнтэй дайсагнадаг Сатаны биелэл (мэдээж энэ нь ч бас хүн) бөгөөд эцэстээ аврагддаг нэгэн нь бас л хүн юм. Ийм болохоор Бурханы хувьд бүтээлийн гадаад бүрхүүлтэй хүн болох нь бүр ч илүү чухал юм, ингэснээр Тэр Сатантай бодитоор тулаан хийж, Өөрт нь дуулгаваргүй байдаг, Өөртэй нь адилхан гадаад бүрхүүлтэй хүнийг байлдан дагуулж, Өөртэй нь яг ижилхэн гадаад бүрхүүлтэй, Сатанд хорлогдсон хүнийг аварч чадна. Түүний дайсан бол хүн, Түүний байлдан дагуулалтын бай бол хүн, мөн Түүний авралын бай бол Өөрийнх нь бүтээсэн хүн билээ. Тиймээс Тэр хүн болох ёстой бөгөөд ийм маягаар Түүний ажил хавьгүй илүү хялбар болдог. Тэр Сатаныг ялан дийлж, хүн төрөлхтнийг байлдан дагуулж чаддаг, түүнчлэн хүн төрөлхтнийг аварч чаддаг. Хэдий энэ махбод хэвийн агаад бодит боловч ердийн нэг махбод биш: Тэр ердөө л нэг хүн чанартай махбод биш, харин хүн чанартай, бас бурханлаг чанартай махбод юм. Энэ нь Түүний хүнээс ялгарах ялгаа бөгөөд Бурханы ялгамж чанарын тэмдэг билээ. Зөвхөн ийм махбод л Түүний хийхээр зорьдог ажлыг хийж, махбод дахь Бурханы үйлчлэлийг биелүүлж, хүмүүсийн дундах Түүний ажлыг бүрэн гүйцэлдүүлж чадна. Хэрэв ийм байгаагүй сэн бол хүмүүсийн дундах Түүний ажил ямагт хоосон, өө сэвтэй байх байлаа. Бурхан хэдийгээр Сатаны сүнстэй тулаан хийж, ялалтаа мандуулж чадах ч завхарсан хүний хуучин уг чанарыг хэзээ ч шийдвэрлэж чадахгүй бөгөөд Бурханд дуулгаваргүй, Түүнийг эсэргүүцдэг хүмүүс хэзээ ч Түүний ноёрхол дор орохгүй, өөрөөр хэлбэл, Тэр хэзээ ч хүн төрөлхтнийг байлдан дагуулж, бүх хүн төрөлхтнийг олж авч чадахгүй билээ. Хэрвээ газар дээрх Түүний ажил шийдвэрлэгдэхгүй бол Түүний удирдлага хэзээ ч дуусгавар болохгүй, бүх хүн төрөлхтөн амралтад орж чадахгүй. Хэрвээ Бурхан Өөрийн бүх бүтээлтэй хамт амралтад орж чадахгүй бол ийм удирдлагын ажил хэзээ ч үр дүнтэй байхгүй бөгөөд үүний үрээр Бурханы алдар суу алга болно. Хэдийгээр Түүний махбод ямар ч эрх мэдэлгүй ч Түүний хийдэг ажил үр дүндээ хүрсэн байх болно. Энэ бол Түүний ажлын зайлшгүй чиглэл юм. Түүний махбод эрх мэдэлтэй эсэхээс үл хамааран Бурханы Өөрийн ажлыг хийх чадвартай л бол Тэр бол Бурхан Өөрөө мөн. Энэ махбод хэр хэвийн, эгэл жирийн байх нь хамаагүй, хийх ёстой ажлаа хийж чадна, учир нь энэ махбод бол ердийн нэг хүн биш, харин Бурхан билээ. Хүний хийж чадахгүй ажлыг энэ махбод хийж чаддагийн шалтгаан нь Түүний дотоод мөн чанар ямар ч хүнийхтэй адилгүй бөгөөд Тэр хүнийг аварч чаддагийн шалтгаан нь Түүний ялгамж чанар өөр ямар ч хүнийхээс өөр байдгаас болдог. Тэр бол хүн, үүнээс ч

илүүтэйгээр Бурхан учраас, Тэрээр махан биетэй жирийн хүний хийж чадахгүй ажлыг хийж чаддаг учраас, Өөртэй нь хамт газар дэлхий дээр амьдарч байгаа завхарсан хүнийг аварч чадах учраас энэхүү махбод хүн төрөлхтөнд нэн чухал юм. Хэдий хүнтэй ижилхэн ч гэсэн бие махбодтой болсон Бурхан нь хүн төрөлхтний хувьд ямар ч үнэ цэнтэй хүнээс илүү чухал, учир нь Тэр Бурханы Сүнсний хийж чадахгүй ажлыг хийж чаддаг бөгөөд Бурханы Сүнснээс илүүтэйгээр Бурханд Өөрт нь гэрчлэл хийж чаддаг, Бурханы Сүнснээс илүүтэйгээр хүн төрөлхтнийг бүрэн олж авч чаддаг. Үүний үр дүнд хэдий энэ махбод хэвийн, эгэл жирийн ч гэсэн хүн төрөлхтөнд оруулсан Түүний хувь нэмэр, хүн төрөлхтний оршин тогтнол дахь Түүний ач холбогдол нь Түүнийг ихэд эрхэм нандин болгодог бөгөөд энэ махбодын жинхэнэ үнэ цэн, ач холбогдол ямар ч хүний хувьд хэмжээлшгүй юм. Хэдийгээр энэ махбод Сатаныг шууд устгаж чадахгүй ч гэсэн Өөрийн ажлыг ашиглан хүн төрөлхтнийг байлдан дагуулж, Сатаныг ялж, Сатаныг Өөрийн ноёрхолд бүрэн захирагдуулж чадна. Бурхан бие махбодтой болсон болохоор Сатаныг ялан дийлж, хүн төрөлхтнийг аварч чаддаг. Тэр Сатаныг шууд устгадаггүй, харин махбод болж, Сатаны завхруулсан хүн төрөлхтнийг байлдан дагуулах ажил хийдэг. Ийм маягаар Тэр бүтээлүүдийн дунд Өөртөө илүү сайн гэрчлэл хийж, завхарсан хүн төрөлхтнийг илүү сайн аварч чаддаг. Бие махбодтой болсон Бурхан Сатаныг ялах нь Бурханы Сүнс Сатаныг шууд устгаснаас илүү их гэрчлэл хийдэг, мөн илүү үнэмшилтэй байдаг. Махбод дахь Бурхан, Бүтээгчийг мэдэхэд нь хүнд илүү сайн тусалж, бүтээлүүдийн дунд Өөртөө илүү сайн гэрчлэл хийж чаддаг.

БУРХАНЫ ОРШДОГ МАХБОДЫН МӨН ЧАНАР

Эхний удаа бие махбодтой болохдоо Бурхан газар дээр гучин гурван жил хагас амьдарсан бөгөөд түүнийхээ гурван жил хагаст нь л үйлчлэлээ гүйцэтгэсэн. Тэрээр ажиллаж байх үедээ болон Өөрийн ажлыг эхлэхээс өмнө аль алинд нь хэвийн хүн чанартай байсан юм; Тэрээр хэвийн хүн чанартаа гучин гурван жил хагас амьдарсан. Сүүлийн гурван жил хагасын туршид Тэрээр бие махбодтой болсон Бурхан гэдгээ илчилсэн юм. Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхлэхээсээ өмнө бурханлаг чанараа харуулалгүй, жирийн, хэвийн хүн чанартайгаар гарч ирсэн ба албан ёсоор Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж эхэлсний дараа л бурханлаг чанар нь илэрхийлэгдсэн. Эхний тэр хорин есөн жил дэх Түүний амьдрал, ажил нь Тэр бол жинхэнэ хүн, хүний хүү, бие махбод гэдгийг харуулж байв; учир нь Түүний үйлчлэл хорин есөн наснаас нь хойш л жинхэнээсээ эхэлсэн юм. “Бие махбодтой болох” нь Бурхан махбодоор илрэх явдал; Бурхан Өөрийн бүтээсэн хүн төрөлхтний дунд махбодын дүрээр ажилладаг. Иймээс, бие махбодтой болохын тулд Бурхан эхлээд махбод буюу хэвийн хүн чанартай махбод байх ёстой; энэ нь хамгийн үндсэн урьдач нөхцөл юм. Үнэндээ, Бурхан бие махбодтой болохын цаад учир нь Бурхан

махбодод амьдарч, ажилладаг бөгөөд чухам мөн чанартаа Бурхан махбод болж, хүн болдог. Бие махбодтой болсон Бурханы амьдрал, ажлыг хоёр үе шатанд хуваж болно. Эхнийх нь үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө Түүний амьдардаг амьдрал. Тэрээр хэвийн хүний гэр бүлд, туйлын хэвийн хүн чанартайгаар амьдарч, хүний амьдралын хэвийн ёс суртахуун, хуулийг дуулгавартай дагаж, хүний хэвийн хэрэгцээ (хоол, хувцас, нойр, орон байр), хүний хэвийн сул талууд болон хүний хэвийн сэтгэл хөдлөлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, энэхүү эхний үе шатанд Тэрээр бурханлаг биш, бүхэлдээ хэвийн хүн чанартайгаар амьдарч, хүний бүх хэвийн үйл ажиллагааг эрхэлдэг. Хоёр дахь үе шат нь Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэж эхэлсний дараа Түүний амьдардаг амьдрал юм. Тэр мөн л эгэл хүний бүрхүүлтэй хэвийн хүн чанарт оршин, гаднаа ямар ч ер бусын тэмдэг үзүүлдэггүй. Гэсэн ч Тэр гагцхүү Өөрийн үйлчлэлийн төлөө л амьдардаг ба энэ хугацаанд Түүний хэвийн хүн чанар бүхэлдээ бурханлаг чанарынх нь хэвийн ажлыг хадгалахын төлөө оршдог, учир нь тэр үед Түүний хэвийн хүн чанар үйлчлэлээ хэрэгжүүлж чадахуйц хэмжээнд төлөвшсөн байдаг. Иймээс Түүний амьдралын хоёр дахь үе шат нь хэвийн хүн чанарааараа Өөрийнхөө үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ нь хэвийн хүн чанар болон бүрэн дүүрэн бурханлаг чанарын хоёулангийнх нь амьдрал юм. Амьдралынхаа эхний үе шатанд Тэр бүрэн энгийн хүн чанараар амьдардгийн шалтгаан бол Түүний хүн чанар нь бурханлаг ажлыг нь хараахан бүрэн хадгалж чаддаггүй, хараахан төлөвшөөгүй байдаг; Түүний хүн чанар төлөвшиж гүйцэн, Өөрийн үйлчлэлийг үүрэх чадвартай болсны дараа л Тэр гүйцэтгэх учиртай үйлчлэлээ хэрэгжүүлж эхэлж чадна. Махбод болохын хувиар Тэр өсөж, төлөвших хэрэгтэй тул Түүний амьдралын эхний үе шат нь хэвийн хүн чанарын амьдрал байдаг байхад хоёр дахь үе шатанд Түүний хүн чанар нь ажлаа хийж, үйлчлэлээ хэрэгжүүлэх чадвартай болдог учраас Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх үеийн бие махбодтой болсон Бурханы амьдрал нь хүн чанар болон бүрэн бурханлаг чанарыг хоёуланг нь агуулсан амьдрал байдаг. Хэрвээ бие махбодтой болсон Бурхан төрсөн мөчөөсөө л Өөрийн үйлчлэлийг жинхэнээсээ эхэлж, ер бусын тэмдэг, гайхамшгуудыг үзүүлсэн бол Түүнд бие махбодын мөн чанар байхгүй байх байсан юм. Тиймээс Түүний хүн чанар бие махбодынх нь мөн чанарын төлөө оршдог; хүн чанаргүй ямар ч махан бие байж болохгүй бөгөөд хүн чанаргүй хүн бол хүн биш. Ийм маягаар, Бурханы махбодын хүн чанар бол Бурханы махбод болсон биеийн төрөлхийн чанар юм. “Бурхан махбод болох үедээ тэр чигтээ бурханлаг чанартай бөгөөд огтхон ч хүн биш” гэж хэлэх нь доромжлол юм, учир нь энэхүү мэдэгдэл ердөө оршин байдаггүй бөгөөд бие махбодтой болох зарчмыг зөрчдөг. Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэж эхэлснийхээ дараа ч гэсэн, ажлаа хийх үедээ Тэрээр хүний гадаад бүрхүүлтэй бурханлаг чанар дотроо амьдарсаар байдаг; яг тэр үед Түүний хэвийн хүн чанар нь хэвийн махбодоор ажлаа гүйцэтгэх боломжийг Өөрийн бурханлаг чанарт олгох цорын ганц зорилготой байдаг. Иймээс ажил гүйцэтгэгч нь Түүний хүн чанарт оршин буй бурханлаг чанар юм. Түүний хүн чанар биш, харин

бурханлаг чанар ажиллаж байгаа ч энэхүү бурханлаг чанар нь Түүний хүн чанар дотор нуугдаж байдаг; мөн чанартаа, Түүний хүн чанар биш, харин бүрэн бурханлаг чанар ажлыг нь хийдэг. Гэхдээ ажлыг гүйцэтгэгч нь Түүний махбод юм. Бурхан хүний бүрхүүлтэй, хүний мөн чанартай, бас Бурханы мөн чанартайгаар махан биед амьдардаг Бурхан болдог учраас Тэр бол хүн, гэхдээ бас Бурхан гэж хэлж болох юм. Тэр бол Бурханы мөн чанартай хүн учраас бүтээгдсэн бүх хүнээс дээгүүр, Бурханы ажлыг гүйцэтгэж чадах өөр ямар ч хүнээс дээгүүр байдаг. Иймээс Түүнийх шиг хүний бүрхүүлтэй бүх хүний дундаас, хүн чанарыг эзэмшдэг бүх хүний дундаас зөвхөн Тэр л бие махбодтой болсон Бурхан Өөрөө бөгөөд бусад нь бүгд бүтээгдсэн хүн билээ. Хэдийгээр тэд бүгдээрээ хүн чанартай ч гэсэн, бүтээгдсэн хүмүүст хүн чанар л байдаг байхад бие махбодтой болсон Бурхан бол өөр: Түүний махбод хүн чанартай байдгаар зогсохгүй, үүнээс ч чухал нь бурханлаг чанартай байдаг. Түүний хүн чанарыг махбодынх нь гадаад төрхөөс болон өдөр тутмын амьдралаас нь харж болно, гэхдээ Түүний бурханлаг чанарыг ухамсарлахад хэцүү байдаг. Яагаад гэвэл, Түүний бурханлаг чанар Түүнд хүн чанар байгаа үед л илэрхийлэгддэг ба хүмүүсийн төсөөлдөгтэй адил ер бусын байдаггүй, үүнийг харах нь хүмүүст туйлын хэцүү байдаг. Өнөөдөр ч гэсэн бие махбодтой болсон Бурханы жинхэнэ мөн чанарыг ойлгох нь хүмүүст хамгийн хэцүү. Намайг энэ талаар ийм ихийг ярьсны дараа ч гэсэн энэ нь та нарын дийлэнхэд нууц хэвээр байдаг гэж Би бодож байна. Үнэндээ, энэ асуудал маш энгийн: Бурхан махбод болдог тул Түүний мөн чанар нь хүн чанар ба бурханлаг чанарын хослол юм. Энэ хослолыг Бурхан Өөрөө буюу газар дээрх Бурхан Өөрөө гэж нэрлэдэг.

Есүсийн газар дээр амьдарсан амьдрал нь махбодын хэвийн амьдрал байлаа. Тэрээр махбодынхоо хэвийн хүн чанараар амьдарсан. Өөрийн ажлыг хийж, үгээ хэлж, эсвэл өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах, тийм ер бусын зүйлсийг хийх эрх мэдэл нь ерөнхийдөө Түүнийг үйлчлэлээ эхлэх хүртэл нь харагдаагүй. Хорин есөн наснаас өмнөх, Өөрийнхөө үйлчлэлийг эхлэхээс өмнөх амьдрал нь Түүнийг ердөө л хэвийн махбод бүхий бие байсан гэдгийг хангалттай нотолсон. Үүнээс болж, мөн Тэр Өөрийн үйлчлэлийг хараахан эхлээгүй байсан учраас хүмүүс Түүнээс ямар ч бурханлаг байдлыг олж хараагүйн дээр ердөө л тухайн үед зарим хүн Түүнийг Иосефын хүү гэж итгэдэг байсан тул ердийн хүн, эгэл хүн л гэж харж байсан юм. Хүмүүс Түүнийг жирийн хүний хүү гэж бодсон бөгөөд Бурханы махбод болсон бие гэж таних ямар ч аргагүй байлаа; Өөрийнхөө үйлчлэлийг гүйцэтгэх явцад олон гайхамшиг үзүүлж байхад нь хүртэл ихэнх хүн Түүнийг Иосефын хүү гэсээр байсан, учир нь Тэр бол гаднаа хэвийн хүн чанарын бүрхүүлтэй Христ байсан юм. Түүний хэвийн хүн чанар болон ажлын аль аль нь, анх удаа бие махбодтой болсны ач холбогдлыг биелүүлэхийн төлөө, Бурхан махбодод бүрмөсөн ирж, үнэхээр эгэл жирийн хүн болсныг батлахын төлөө оршиж байлаа. Тэрээр Өөрийн ажлыг эхлэхээс өмнө хэвийн хүн чанартай байсан нь эгэл жирийн махбод байсных нь нотолгоо байв; дараа нь Тэр ажилласан нь ч бас эгэл жирийн махбод байсныг нь

нотолсон, учир нь Тэр хэвийн хүн чанартай махбодоор тэмдэг, гайхамшиг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулж байсан билээ. Тэр гайхамшиг үзүүлж чаддаг байсны шалтгаан нь Түүний махбод Бурханы эрх мэдэлтэй, Бурханы Сүнсний өмссөн махбод байсан юм. Бурханы Сүнснээс болоод Тэр ийм эрх мэдэлтэй байсан ба Тэр махбод байгаагүй гэсэн үг биш. Өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь Өөрийн үйлчлэлээр гүйцэтгэх хэрэгтэй байсан ажил, Түүний хүн чанарт нуугдсан бурханлаг чанарын илэрхийлэл байсан бөгөөд Тэр ямар ч тэмдэг үзүүлж, эрх мэдлээ яаж ч харуулсан байсан, хэвийн хүн чанараар амьдарч, хэвийн махбод хэвээр байсан. Загалмай дээр үхсэнийхээ дараа дахин амилах хүртлээ Тэр хэвийн махбод дотор оршиж байсан. Нигүүлсэл хайрлаж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь бүгд Түүний үйлчлэлийн нэг хэсэг байсны дээр эдгээр нь бүгд Өөрийн хэвийн махбодод байхдаа гүйцэтгэсэн Түүний ажил байв. Цовдлогдохоосоо өмнө, Тэр юу ч хийж байсан, хэвийн хүний махбодоо хэзээ ч орхиогүй. Тэр бол Бурханы ажлыг хийж буй Бурхан Өөрөө байсан ч Бурханы махбод болсон бие байсан учраас хоол идэж, хувцас өмсөж, хүний хэвийн хэрэгцээтэй, хүний хэвийн эрүүл ухаан, хэвийн сэтгэхүйтэй байсан. Энэ бүхэн нь Тэр хэвийн хүн байсны нотолгоо бөгөөд Бурханы махбод болсон бие ер бусын биш, харин хэвийн хүн чанартай махбод байсныг нотолсон. Түүний ажил бол эхний удаа бие махбодтой болсон Бурханы ажлыг гүйцэлдүүлж, эхний удаа бие махбодтой болсон Бурханы гүйцэтгэх учиртай үйлчлэлийг хэрэгжүүлэх явдал байв. Бие махбодтой болохын ач холбогдол нь эгэл, жирийн хүн Бурханы Өөрийн ажлыг хэрэгжүүлдэг; өөрөөр хэлбэл, Бурхан бурханлаг ажлаа хүн чанараар хэрэгжүүлж, улмаар Сатаныг ялдаг. Бие махбодтой болох гэдэг нь Бурханы Сүнс махбод болдог, өөрөөр хэлбэл, Бурхан махбод болдог гэсэн үг; тэрхүү махбодын хийдэг ажил нь махбодод биеллээ олж, махбодоор илэрхийлэгддэг Сүнсний ажил юм. Бурханы махбодоос өөр хэн ч бие махбодтой болсон Бурханы үйлчлэлийг хэрэгжүүлж чадахгүй; өөрөөр хэлбэл, өөр хэн ч биш, зөвхөн Бурханы махбод болсон бие, энэхүү хэвийн хүн чанар л бурханлаг ажлыг илэрхийлж чадна. Бурхан анх ирэх үедээ хорин есөн нас хүрэхээсээ өмнө хэвийн хүн чанартай байгаагүй бол, хэрвээ төрөнгүүтээ л гайхамшиг үзүүлж, хэлд ормогцоо л тэнгэрийн хэлээр ярьж, газар дээр анх хөл тавьсан үеэсээ л хорвоогийн бүх хэрэг явдлыг ухан ойлгож, хүн бүрийн бодол, санаа зорилгыг ялган таньж чаддаг байсан бол, ийм хүнийг хэвийн хүн гэж нэрлэж болохгүй байх байсан бөгөөд ийм махбодыг хүний махан бие гэж нэрлэж болохгүй байх байлаа. Хэрвээ Христ ийм байсан бол Бурхан бие махбодтой болохын мөн чанар, утга учир алдагдах байв. Тэр хэвийн хүн чанартай байдаг нь махбод болсон Бурхан мөн гэдгийг нь нотолдог; Тэрээр хүний хэвийн өсөлтийн үйл явцыг туулдаг нь хэвийн махбод мөн гэдгийг нь улам батлан харуулдаг; түүнчлэн, Тэр бол махбод болсон Бурханы Үг, Бурханы Сүнс гэдгийг Түүний ажил хангалттай нотолдог. Ажлынхаа хэрэгцээнээс болж л Бурхан махбод болдог; өөрөөр хэлбэл, ажлын энэ үе шатыг махбодоор хийх ёстой, хэвийн хүн чанараар гүйцэтгэх ёстой. Энэ нь “Үг махбод болох”, “Үг махбодоор илрэхийн”

урьдач нөхцөл, Бурхан хоёр удаа бие махбодтой болсны цаад үнэн түүх билээ. Есүс насан туршдаа гайхамшиг үзүүлсэн, газар дээрх ажлаа дуусгах хүртэл хэвийн хүн чанарын ямар ч шинж тэмдгийг харуулаагүй, Түүнд хүний хэвийн хэрэгцээ, сул тал, хүний сэтгэл хөдлөл байгаагүй, амьдралын үндсэн хэрэгцээ шаардлагагүй байсан, хэвийн хүн шиг ч боддоггүй байсан гэж хүмүүс итгэж магадгүй. Тэд Түүнийг хүний хэрээс хэтэрсэн оюун ухаантай, ер бусын хүн чанартай л гэж төсөөлдөг. Нэгэнт Тэр Бурхан учраас хэвийн хүмүүс шиг бодож, амьдрах ёсгүй, хэвийн хүн буюу жинхэнэ хүн л хэвийн хүний бодлыг бодож, хүний хэвийн амьдралаар амьдарч чадна гэж тэд итгэдэг. Эдгээр нь бүгд хүний санаа, хүний үзэл бөгөөд эдгээр үзэл Бурханы ажлын анхдагч санаа зорилгод харшилдаг. Хүний хэвийн сэтгэхүй нь хүний хэвийн эрүүл ухаан, хэвийн хүн чанарыг хадгалдаг; хэвийн хүн чанар нь махбодын хэвийн үйл ажиллагааг хадгалдаг; махбодын хэвийн үйл ажиллагаа нь махбодыг бүхэлд нь хэвийн амьдруулдаг. Бурхан тийм махбодод ажиллаж байж л бие махбодтой болсон зорилгоо биелүүлж чадна. Хэрвээ бие махбодтой болсон Бурхан зөвхөн махбодын гадаад бүрхүүлтэй боловч хэвийн хүний бодлыг боддоггүй бол энэхүү махбодод жинхэнэ хүн чанар бүү хэл, хүний эрүүл ухаан ч байхгүй. Хүн чанаргүй ийм махбод нь бие махбодтой болсон Бурханы гүйцэтгэх учиртай үйлчлэлийг биелүүлж яаж чадах юм бэ? Хэвийн оюун ухаан нь хүний амьдралын бүх талыг хадгалдаг; хэвийн оюун ухаангүй бол хүн, хүн биш байх болно. Өөрөөр хэлбэл, хэвийн бодол боддоггүй хүн бол сэтгэцийн өвчтэй бөгөөд ямар ч хүн чанаргүй, зөвхөн бурханлаг чанартай Христийг Бурханы махбод болсон бие гэж хэлж болохгүй. Тэгвэл Бурханы махбод болсон бие ямар ч хэвийн хүн чанаргүй байж яаж болох юм бэ? Христэд ямар ч хүн чанар байхгүй гэж хэлэх нь доромжлол бус уу? Хэвийн хүмүүсийн явуулдаг бүх үйл ажиллагаа нь хүний хэвийн оюун ухааны ажиллагаанд түшиглэдэг. Үүнгүйгээр, хүмүүс этгээд авирлах байсан; тэр ч бүү хэл тэд хар цагаан, сайн мууг ялгаж чадахгүй байх байсан; тэгээд хүний ёс зүй, ёс суртахууны зарчимгүй байх байсан. Үүний адилаар, хэрвээ бие махбодтой болсон Бурхан хэвийн хүн шиг боддоггүй байсан бол жинхэнэ бие махбод буюу хэвийн махбод биш байх байсан юм. Юм боддоггүй тийм махбод бурханлаг ажлыг гүйцэтгэж чадахгүй байх байлаа. Тэрээр хэвийн махан биеийн үйл ажиллагааг хэвийн байдлаар явуулж чадахгүй, газар дээр хүмүүстэй хамт амьдарч бүр ч чадахгүй байх байв. Тэгээд Бурхан бие махбодтой болсны ач холбогдол, Бурхан махбодод ирэхийн гол мөн чанар алдагдах байсан юм. Бие махбодтой болсон Бурханы хүн чанар нь махбод дахь хэвийн бурханлаг ажлыг хадгалахын төлөө оршдог; Түүний хэвийн хүний сэтгэхүй нь хэвийн хүн чанар болоод махбодынх нь бүх хэвийн үйл ажиллагааг хадгалдаг. Түүний хэвийн хүний сэтгэхүй нь махбод дахь Бурханы ажлыг хадгалахын тулд оршдог гэж хэлж болох юм. Хэрвээ энэхүү махбодод хүний хэвийн оюун ухаан байгаагүй бол Бурхан махбодоор ажиллаж чадахгүй байх байсан ба махбодоор хийх хэрэгтэй зүйлс нь хэзээ ч гүйцэлдэхгүй байх байлаа. Бие махбодтой болсон Бурханд хүний хэвийн оюун ухаан байдаг

хэдий ч Түүний ажилд хүний бодол холилддоггүй; Тэр хүний хэвийн бодлоор бус, харин оюун ухаантай хүн чанарыг эзэмшсэн урьдач нөхцөл дор хэвийн оюун ухаантай хүн чанараар Өөрийн ажлыг явуулдаг. Түүний махбодын бодол хэчнээн сүрлэг байх нь хамаагүй, Түүний ажилд логик юм уу сэтгэлгээ холилддоггүй. Өөрөөр хэлбэл, Түүний ажил нь Түүний махан биеийн оюун ухаанаас төрөн гардаггүй, харин Түүний хүн чанар дахь бурханлаг ажлын шууд илэрхийлэл юм. Түүний бүх ажил нь Түүний биелүүлэх ёстой үйлчлэл бөгөөд нэгийг нь ч Түүний уураг тархи бодож олдоггүй. Жишээлбэл, өвчтэйг эдгээх, чөтгөрийг зайлуулах болон цовдлол нь Түүний хүний оюун ухааны үр дүн байгаагүй, хүний оюун ухаантай ямар ч хүн үүнийг хийж чадахгүй байх байсан юм. Үүний адилаар, өнөөдрийн байлдан дагуулалтын ажил бол бие махбодтой болсон Бурханы хэрэгжүүлэх ёстой үйлчлэл боловч энэ нь хүний хүслийн ажил биш, харин Түүний бурханлаг чанарын хийх ёстой ажил, махан биетэй ямар ч хүний хийж чадахгүй ажил билээ. Иймээс бие махбодтой болсон Бурханд хүний хэвийн оюун ухаан, хэвийн хүн чанар байх ёстой, учир нь Тэр хэвийн оюун ухаантай хүн чанараар Өөрийн ажлыг гүйцэтгэх ёстой. Энэ бол бие махбодтой болсон Бурханы ажлын мөн чанар, бие махбодтой болсон Бурханы жинхэнэ мөн чанар юм.

Есүс ажлаа гүйцэтгэхээс өмнө ердөө л хэвийн хүн чанарааraa амьдарч байлаа. Тэр бол Бурхан мөн гэдгийг хэн ч таньж чадаагүй, бие махбодтой болсон Бурхан гэдгийг нь хэн ч олж мэдээгүй; хүмүүс Түүнийг тун жирийн хүн гэж л мэддэг байсан. Түүний туйлын эгэл жирийн, хэвийн хүн чанар нь Бурхан бие махбодтой болсны нотолгоо, мөн Нигүүлслийн эрин үе нь Сүнсний ажлын эрин үе биш, харин бие махбодтой болсон Бурханы ажлын эрин үе гэдгийн нотолгоо байлаа. Энэ нь, Бурханы Сүнс махбодод бүрэн биеллээ олж, бие махбодтой болсон Бурханы эрин үед Түүний махбод Сүнсний бүх ажлыг гүйцэтгэнэ гэдгийн нотолгоо байв. Хэвийн хүн чанартай Христ бол дотор нь Сүнс биеллээ олсон махбод бөгөөд хэвийн хүн чанар, хэвийн эрүүл ухаан, хүний бодлыг эзэмшиж байдаг. “Биеллээ олно” гэдэг нь Бурхан хүн болж, Сүнс махбод болдог гэсэн үг; илүү тодорхой хэлэх юм бол, энэ нь Бурхан Өөрөө хэвийн хүн чанартай махбодод оршиж, үүгээрээ Өөрийн бурханлаг ажлыг илэрхийлдэг үе юм—энэ нь биеллээ олсон буюу бие махбодтой болсон гэсэн үг билээ. Эхний удаад бие махбодтой болох үед Бурханы ажил нь золин аврахын төлөө байсан учраас өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах шаардлагатай байсан. Бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд Тэрээр энэрэнгүй, өршөөнгүй байх хэрэгтэй байв. Цовдлогдохоосоо өмнө Түүний хийсэн ажил нь өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах явдал байсан нь хүнийг нүгэл, бузар муухайгаас аврах авралыг нь зөгнөсөн юм. Энэ нь Нигүүлслийн эрин үе байсан учраас Түүний хувьд өвчтэй хүмүүсийг эдгээж, улмаар тухайн эрин үе дэх нигүүлслийн бэлгэдэл болох тэмдэг, гайхамшгийг үзүүлэх шаардлагатай; учир нь Нигүүлслийн эрин үе бол хүмүүсийн Есүст итгэх итгэлийн бэлгэ тэмдэг болох амар тайван, баяр баясал, материаллаг ерөөлөөр бэлгэдсэн нигүүлслийг өгөхөд

төвлөрсөн. Өөрөөр хэлбэл, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулж, нигүүлсэл хайрлах нь Нигүүлслийн эрин үе дэх Есүсийн махбодын төрөлхийн чадвар байсан ба махбодод биеллээ олсон Сүнсний ажил байсан юм. Гэхдээ тийм ажил гүйцэтгэж байх явцдаа Тэр махбодод амьдарч байсан бөгөөд махбодоос хэтрэн гараагүй. Тэр анагааж эдгээх ямар үйл хийсэн нь хамаагүй, мөн л хэвийн хүн чанартай байсан бөгөөд хэвийн хүний амьдралаар амьдарсан хэвээр байсан. Бие махбодтой болсон Бурханы эрин үед махбод нь Сүнсний бүх ажлыг гүйцэтгэдэг гэж хэлдгийн минь шалтгаан бол, Тэр ямар ч ажил хийлээ гэсэн үүнийгээ махбодоор хийсэн билээ. Гэвч Түүний ажлаас болоод хүмүүс Түүний махбодыг бүрэн дүүрэн бие махбодын мөн чанартай гэж үзээгүй, учир нь энэхүү махбод гайхамшиг үзүүлж, зарим нэг онцгой мөчид махан биеэс даван гарсан зүйлсийг хийж байсан юм. Мэдээж, Түүнийг үйлчлэлээ эхэлсний дараа л дөчин өдрийн турш соригдох, уулан дээр хувирах гэх мэтийн энэ бүх явдал тохиолдсон. Иймээс Есүсийн хувьд, Бурхан бие махбодтой болохын утга учир бүрэн гүйцэлдээгүй, харин зөвхөн хагас биелсэн. Өөрийн ажлыг эхлэхээс өмнө махбодод амьдарсан Түүний амьдрал бүх талаараа тун хэвийн байсан. Ажлаа эхэлснийхээ дараа Тэрээр махбодынхоо гадаад бүрхүүлийг л хадгалсан. Түүний ажил бурханлаг чанарын илэрхийлэл байсан учраас махан биеийн хэвийн ажиллагаанаас даван гарсан юм. Эцсийн эцэст, Бурханы махбод болсон бие нь мах, цустай хүмүүсийн биеэс ялгаатай байлаа. Мэдээж, Түүний өдөр тутмын амьдралд бусдын адилаар хоол, хувцас, нойр, орон байр шаардагдаж, бүх хэвийн хэрэгцээ хэрэгтэй байсан ба Тэрээр хэвийн хүний эрүүл ухаантай, хэвийн хүн шиг бодолтой байсан. Түүний хийсэн ажил ер бусын байснаас бусдаар бол хүмүүс Түүнийг хэвийн хүн гэж үзсээр байлаа. Үнэндээ Тэр юу ч хийсэн бай, жирийн, хэвийн хүн чанараар амьдарсан бөгөөд Тэр ажлаа гүйцэтгэж байсан учраас өөр ямар ч хэвийн хүмүүсийнхээс илүүгээр Түүний эрүүл ухаан тун хэвийн, бодол нь нэн тодорхой байсан. Ийм бодол, эрүүл ухаантай байх нь бие махбодтой болсон Бурханд чухал байсан, учир нь эрүүл ухаан нь тун их хэвийн, бодол нь маш тодорхой байдаг махбодоор бурханлаг ажил илэрхийлэгдэх хэрэгтэй байв—зөвхөн ийм маягаар л Түүний махбод бурханлаг ажлыг илэрхийлж чадах байсан юм. Газар дээр амьдарсан гучин гурван жил хагасынхаа туршид Есүс хэвийн хүн чанараа хадгалсан боловч гурван жил хагасын үйлчлэлийн ажлаас нь үүдэн хүмүүс Түүнийг маш гайхалтай, өмнөхөөсөө хамаагүй илүү ер бусын болсон гэж боджээ. Бодит байдал дээр Есүсийн хэвийн хүн чанар нь Түүнийг үйлчлэлээ эхлэхээс өмнө нь ч, дараа нь ч өөрчлөгдөөгүй хэвээр үлдсэн; Түүний хүн чанар цаг ямагт адилхан байсан боловч Өөрийнхөө үйлчлэлийг эхлэхийн өмнөх ба дараах ялгааных нь улмаас Түүний махбодтой холбоотой хоёр өөр үзэл бодол гарч ирсэн. Хүмүүс юу гэж бодож байсан нь хамаагүй, бие махбодтой болсон Бурхан анхдагч, хэвийн хүн чанараа бүхий л хугацаанд хэвээр хадгалсан, учир нь Бурхан нэгэнт бие махбод болсон болохоор махбодод буюу хэвийн хүн чанартай махбодод амьдарч байсан юм. Тэр Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлж байна уу, үгүй юу гэдгээс

үл хамааран, Түүний махбодын хэвийн хүн чанарыг арилгаж болохгүй, учир нь хүн чанар бол махан биеийн үндсэн мөн чанар билээ. Есүсийг үйлчлэлээ хэрэгжүүлэхээс өмнө Түүний махбод тун хэвийн хэвээр байж, ердийн хүний бүх үйл ажиллагааг гүйцэтгэж байсан; Тэрээр ердөө ч ер бусын харагдаагүй, ямар ч гайхалтай тэмдэг үзүүлээгүй. Тухайн үед Тэрээр Бурханыг шүтэн мөргөдөг маш эгэл хүн байсан, гэхдээ Түүний эрэл хайгуул өөр ямар ч хүнийхээс илүү үнэнч, илүү чин шударга байсан билээ. Түүний туйлын хэвийн хүн чанар ийнхүү илэрхийлэгдэж байсан юм. Өөрийнхөө үйлчлэлийг явуулахаас өмнө Тэр ямар ч ажил хийгээгүй учраас хэн ч Түүний ялгамж чанарыг мэдээгүй, Түүний махбод бусад бүх хүнийхээс өөр гэдгийг хэн ч таньж чадаагүй, учир нь Тэр ганц ч ид шид үзүүлээгүй, Бурханы ажлын өчүүхэн хэсгийг ч гүйцэтгээгүй байсан. Гэхдээ, үйлчлэлээ гүйцэтгэж эхэлснийхээ дараа Тэрээр хэвийн хүн чанарын гадаад бүрхүүлээ хадгалж, хэвийн хүний эрүүл ухаантай амьдарсаар байсан хэр нь Бурханы Өөрийн ажлыг хийж, Христийн үйлчлэлийг Өөртөө авч, мах цуснаас бүрдсэн, үхэх үйлтэй хүмүүсийн хийж чадахааргүй ажлыг хийж эхэлсэн учраас Тэр хэвийн хүн чанаргүй бөгөөд бүрэн дүүрэн хэвийн махбод биш, харин бүрэн бус махбод гэж хүмүүс боджээ. Түүний гүйцэтгэсэн ажлаас болоод хүмүүс Түүнийг хэвийн хүн чанаргүй, махбод дахь Бурхан гэлцсэн. Энэ нь эндүү ташаа ойлголт юм, учир нь хүмүүс Бурхан бие махбодтой болохын ач холбогдлыг ухаараагүй. Энэхүү буруу ойлголт нь, махбодоор хийгдсэн Бурханы ажил нь хэвийн хүн чанартай махбодоор илэрхийлэгдсэн бурханлаг ажил байснаас үүдэн гарсан. Бурхан махбодоор хувцаслаж, махбод дотор оршсон бөгөөд хүн чанараар хийсэн ажил нь Түүний хүн чанарын хэвийн байдлыг бүрхэгдүүлсэн юм. Ийм учраас хүмүүс Бурханд хүн чанар байхгүй, гагцхүү бурханлаг чанар бий гэж итгэжээ.

Эхний удаа бие махбодтой болохдоо Бурхан бие махбодтой болсон Бурханы ажлыг гүйцэлдүүлээгүй; Тэр ердөө ажлын эхний үе шатыг гүйцээсэн ба Бурхан үүнийг махбодоор хийх шаардлагатай байв. Иймээс, бие махбодтой болох ажлыг дуусгахын тулд Бурхан дахин нэг удаа махбодод эргэн ирээд махбодын бүх л хэвийн, бодитой байдлыг амьдран харуулдаг, өөрөөр хэлбэл, Бурханы Үгийг бүхэлдээ хэвийн, эгэл махбодоор илэрхийлж, улмаар махбодоор хийж чадалгүй орхисон ажлаа гүйцээдэг. Бурханы махбод болсон хоёр дахь бие нь мөн чанарааараа эхнийхтэй адил боловч эхнийхээсээ бүр илүү бодитой, бүр илүү хэвийн байдаг. Үүний үр дүнд, Бурханы махбод болсон хоёр дахь биеийн туулдаг зовлон эхнийхээс илүү их байх боловч энэхүү зовлон нь махбод дахь Түүний үйлчлэлийн үр дүн бөгөөд завхарсан хүний зовлонгоос ялгаатай байдаг. Энэ нь бас Түүний махбодын хэвийн, бодитой байдлаас урган гардаг. Тэр Өөрийн үйлчлэлийг туйлын хэвийн, бодитой махбодоор хэрэгжүүлдэг учраас махбод нь асар их зовлон зүдүүрийг туулах ёстой. Энэхүү махбод хэвийн, бодитой байх тусам Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэхдээ төдий чинээ их зовно. Бурханы ажил огтхон ч ер бусын биш, маш эгэл жирийн махбодоор илэрхийлэгддэг. Түүний махбод хэвийн бөгөөд

хүнийг аврах ажлыг ч бас үүрэх ёстой учраас Тэрээр ер бусын махан биеэс ч илүү их зовдог—энэ бүх зовлон нь Түүний махбодын бодитой, хэвийн байдлаас үүсэн гардаг. Бурханы махбод болсон хоёр биеийн үйлчлэлээ гүйцэтгэх явцдаа туулсан зовлонгоос бие махбодтой болохын мөн чанарыг харж болно. Махбод нь хэвийн байх тусам ажлаа хийх явцдаа Тэр төдий чинээ их зовлон бэрхшээл туулах ёстой байдаг; ажлыг хийж буй махбод бодитой байх тусам хүмүүсийн үзэл төдий чинээ хатуу болдог, мөн төдий чинээ их аюул Түүнд тохиолдох магадлалтай байдаг. Түүнчлэн махбод нь бодитой байх тусам, мөн махбод нь хэвийн хүний бүрэн эрүүл ухаан болон хэрэгцээтэй байх тусам Тэр Бурханы ажлыг махбодоор хийх төдий чинээ чадвартай байдаг. Есүсийн махбод загалмай дээр цовдлогдсон, Тэр Өөрийн махбодыг нүглийн тахил болгосон; хэвийн хүн чанартай махбодын тусламжтайгаар Тэр Сатаныг ялж, хүнийг загалмайнаас бүрэн аварсан. Хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурхан нь бүрэн төгс махбодоор байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэж, Сатаныг ялдаг. Бүрмөсөн хэвийн, бодитой махбод л байлдан дагуулалтын ажлыг бүхэлд нь хэрэгжүүлж, хүчирхэг гэрчлэл хийж чадна. Өөрөөр хэлбэл, хүнийг байлдан дагуулах нь ер бусын ид шид, илчлэлээр бус, махбод дахь Бурханы бодитой, хэвийн байдлаар дамжин үр дүнд хүрдэг. Бие махбодтой болсон энэ Бурханы үйлчлэл нь үг хэлж, улмаар хүнийг байлдан дагуулж, төгс болгох явдал юм; өөрөөр хэлбэл, махбодод биеллээ олсон Сүнсний ажил буюу махбодын үүрэг нь үг хэлж, тэгснээрээ хүнийг бүрэн байлдан дагуулж, илчилж, төгс болгож, таягдан хаях явдал билээ. Иймээс байлдан дагуулалтын ажлаар дамжуулан махбод дахь Бурханы ажил бүрэн гүйцэлдэнэ. Эхний золин авралын ажил нь бие махбодтой болсон Бурханы ажлын ердөө л эхлэл байсан; байлдан дагуулалтын ажлыг хийдэг махбод нь бие махбодтой болохын бүх ажлыг гүйцээнэ. Хүйсийн хувьд нэг нь эрэгтэй, нөгөө нь эмэгтэй бөгөөд үүгээр Бурхан бие махбодтой болохын утга учрыг биелүүлж, Бурханы талаарх хүний үзлийг арилгадаг: Бурхан эрэгтэй, эмэгтэй аль нь ч болж чадах ба мөн чанартаа бол бие махбодтой болсон Бурхан хүйсгүй юм. Тэрээр эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн бөгөөд Түүний хувьд хүйсийн ялгаа байхгүй. Ажлын энэ үе шатанд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлдэггүй, иймээс энэхүү ажил нь үгийн тусламжтайгаар үр дүндээ хүрнэ. Түүнчлэн, үүний шалтгаан нь энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажил бол өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах явдал биш, харин үгээ хэлж, хүнийг байлдан дагуулах явдал юм, өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон энэхүү биеийн эзэмшсэн төрөлх чадвар нь өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах биш, харин үг хэлэх, хүнийг байлдан дагуулах билээ. Хэвийн хүн чанараар хийдэг Түүний ажил ид шидийг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах биш, харин үг хэлэх явдал тул Бурханы махбод болсон хоёр дахь бие нь хүмүүст эхнийхээсээ хавьгүй илүү хэвийн мэт санагддаг. Бурхан бие махбодтой болох нь худал биш гэдгийг хүмүүс хардаг; гэвч бие махбодтой болсон энэхүү Бурхан нь бие махбодтой болсон Есүсээс өөр бөгөөд хоёулаа бие

махбодтой болсон Бурхан мөн хэдий ч Тэд ав адилхан биш. Есүс хэвийн хүн чанартай, жирийн хүн чанартай байсан боловч Түүнийг олон тэмдэг, гайхамшиг дагалдаж байсан. Энэ удаа бие махбодтой болсон Бурханаас хүн ямар ч тэмдэг, гайхамшиг харахгүй, өвчтэйг эдгээж байгааг ч, чөтгөрийг зайлуулж байгааг ч, тэнгис дээгүүр алхахыг ч, эсвэл дөчин өдрийн турш мацаг барихыг ч харахгүй… Тэр Есүсийн хийсэнтэй адилхан ажлыг хийдэггүй бөгөөд энэ нь Түүний махбод мөн чанараараа Есүсийнхээс өөр учраас биш, харин өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь Түүний үйлчлэл биш учраас тэр юм. Тэр Өөрийн ажлыг сүйтгэдэггүй, Өөрийн ажлыг үймүүлдэггүй. Нэгэнт Тэр Өөрийн бодит үгээр хүнийг байлдан дагуулдаг тул хүнийг ид шидээр эрхшээлдээ оруулах гэсний хэрэггүй, иймээс энэ үе шат нь бие махбодтой болох ажлыг төгсгөхийн төлөө байдаг. Өнөөдөр чиний хардаг бие махбодтой болсон Бурхан бол бүхэлдээ махбод бөгөөд Түүнд ер бусын зүйл огт байхгүй. Тэр бусдын адил өвддөг, яг л бусдын адилаар хоол, хувцас хэрэгтэй болдог; Тэр бүхэлдээ махбод юм. Хэрвээ энэ удаа, бие махбодтой болсон Бурхан ер бусын тэмдэг, гайхамшгуудыг үзүүлсэн бол, өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулж, эсвэл нэг үгээр үхүүлж чаддаг байсан бол байлдан дагуулалтын ажлыг явуулж яаж чадах юм бэ? Энэхүү ажил Харь үндэстний дунд түгж яаж чадах юм бэ? Өвчтэйг эдгээж, чөтгөрийг зайлуулах нь Нигүүлслийн эрин үеийн ажил буюу золин авралын ажлын эхний алхам байсан бөгөөд Бурхан хүнийг загалмайнаас аварчихсан болохоор уг ажлыг Тэр дахиж хийхгүй. Хэрвээ эцсийн өдрүүдэд өвчтэйг эдгээн, чөтгөрийг зайлуулж, хүний төлөө цовдлогдсон Есүстэй адилхан нэг “Бурхан” гарч ирэх юм бол тэр “Бурхан” хэдийгээр Библи дэх Бурханы тодорхойлолттой адилхан, хүлээн зөвшөөрөхөд хүнд хялбар байх ч мөн чанартаа Бурханы Сүнсний өмссөн махбод биш, харин муу ёрын сүнсний өмссөн махан бие байна. Учир нь Өөрийнхөө аль хэдийн дуусгасан зүйлийг хэзээ ч давтдаггүй нь Бурханы ажлын зарчим билээ. Иймээс хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь эхнийхийн ажлаас өөр байдаг. Эцсийн өдрүүдэд Бурхан байлдан дагуулалтын ажлыг эгэл жирийн, хэвийн махбодоор биелүүлдэг; Тэрээр өвчтэйг эдгээдэггүй, хүний төлөө цовдлогдохгүй, харин гагцхүү махбодоор үг хэлж, махбодоор хүнийг байлдан дагуулдаг. Зөвхөн тийм махбод л Бурханы махбод болсон бие юм; тийм махбод л махбод дахь Бурханы ажлыг гүйцээж чадна.

Энэ үе шатанд бие махбодтой болсон Бурхан зовлон бэрхшээл туулж байсан ч, эсвэл Өөрийн үйлчлэлийг гүйцэтгэж байсан ч, бие махбодтой болохын утга учрыг биелүүлэхийн төлөө үүнийг хийдэг, учир нь энэ бол Бурхан сүүлчийн удаа бие махбодтой болж байгаа хэрэг юм. Бурхан ердөө хоёр удаа л бие махбодтой болж чадна. Гурав дахь удаа гэж байхгүй. Эхний бие махбод нь эрэгтэй байсан, хоёр дахь нь эмэгтэй, иймээс Бурханы махбодын дүр хүний оюун санаанд гүйцэлдсэн; түүнчлэн, хоёр удаа бие махбодтой болсон нь махбодоор хийх Бурханы ажлыг аль хэдийн дуусгасан. Эхний удаад бие махбодтой болсон Бурхан, бие махбодтой

болохын утга учрыг биелүүлэхийн тулд хэвийн хүн чанарыг эзэмшиж байсан. Энэ удаа ч Тэр бас хэвийн хүн чанартай байдаг, гэхдээ энэ удаа бие махбодтой болсны утга учир нь өөр: Энэ нь илүү гүн гүнзгий бөгөөд Түүний ажил илүү гүн ач холбогдолтой. Бурхан дахин нэг удаа махбод болсны шалтгаан нь бие махбодтой болохын утга учрыг биелүүлэхийн төлөө байдаг. Бурхан Өөрийн ажлын энэ үе шатыг бүрмөсөн дуусгах үед бие махбодтой болохын бүхий л утга учир буюу махбод дахь Бурханы ажил дуусах ба махбодоор хийгдэх өөр ажил цаашид байхаа болино. Өөрөөр хэлбэл, одоогоос эхлээд Бурхан Өөрийнхөө ажлыг хийхийн тулд дахин хэзээ ч махбодод ирэхгүй. Зөвхөн хүн төрөлхтнийг аварч, төгс болгохын тулд л Бурхан бие махбодтой болох ажлыг хийдэг. Өөрөөр хэлбэл, Өөрийнх нь ажлын төлөө байгаагүй л бол Бурхан махбодод ирэх нь ердийн хэрэг биш юм. Махбодод ажиллахаар ирснээрээ Тэр, Бурхан бол махбод, хэвийн, эгэл жирийн хүн атлаа дэлхийг ялгууснаар хаанчилж, Сатаныг ялж, хүн төрөлхтнийг золин аварч, хүн төрөлхтнийг байлдан дагуулж чадна гэдгийг Сатанд харуулдаг! Сатаны ажлын зорилго нь хүн төрөлхтнийг завхруулахын төлөө байхад Бурханы зорилго нь хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг. Сатан хүнийг ёроолгүй нүх рүү урхиддаг байхад Бурхан хүнийг тэндээс авардаг. Сатан бүх хүнээр өөрийгөө шүтүүлдэг, харин Бурхан тэднийг Өөрийнхөө ноёрхолд оруулдаг, учир нь Тэр бол бүтээлийн Эзэн билээ. Энэ бүх ажлыг Бурхан хоёр удаа бие махбодтой болсноор гүйцээсэн. Түүний махбод нь мөн чанартаа хүн чанар болон бурханлаг чанарын нэгдэл бөгөөд хэвийн хүн чанартай байдаг. Иймээс Бурханы махбод болсон биегүйгээр Бурхан хүн төрөлхтнийг аврах үр дүнд хүрч чадахгүй бөгөөд махбодынх нь хэвийн хүн чанар байгаагүй бол махбод дахь Түүний ажил амжилттай болж мөн л чадахгүй байх байсан. Бие махбодтой болсон Бурханы мөн чанар нь хэвийн хүн чанарыг эзэмших ёстойд оршдог; тэгэхгүй бол энэ нь бие махбодтой болох Бурханы анхдагч санаа зорилгод харшлах байв.

Бие махбодтой болохын утга учир Есүсийн ажлын үе шатанд бүрэн биелээгүй гэж Би яагаад хэлдэг вэ? Учир нь Үг бүхэлдээ махбод болоогүй юм. Есүсийн хийсэн зүйл нь махбод дахь Бурханы ажлын ердөө нэг хэсэг байсан; Тэр зөвхөн золин авралын ажлыг л хийсэн ба хүнийг бүрмөсөн олж авах ажлыг хийгээгүй. Энэ шалтгааны улмаас Бурхан эцсийн өдрүүдэд дахин нэгэнтээ махбод болсон. Ажлын энэ үе шатыг ч бас эгэл жирийн махбодоор хийдэг; хүн чанар нь өчүүхэн төдий ч ер бусын биш, туйлын хэвийн хүн үүнийг хийдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан бүрэн төгс хүн болсон; Тэр бол уг ажлыг хэрэгжүүлж буй Бурханы ялгамж чанартай хүн, бүрэн төгс хүн, бүрэн төгс махбод юм. Хүний нүдээр Тэр бол огтхон ч ер бусын биш махан бие бөгөөд хурлын том танхимд шашны талаарх дотоод үнэнийг илчлэх нь бүү хэл, ямар ч гайхамшигтай тэмдэг үзүүлдэггүй, ямар ч ид шид үзүүлдэггүй, тэнгэрийн хэлээр ярьж чаддаг тун эгэл жирийн хүн билээ. Бурханы махбод болсон хоёр дахь биеийн ажил нь хүмүүст эхний махбодын ажилтай тун адилгүй санагддаг, иймээс энэ хоёрт нийтлэг зүйл огт байхгүй мэт

санагддаг бөгөөд эхнийхийн ажлын юуг ч энэ удаа харж чадахгүй. Хэдийгээр Бурханы махбод болсон хоёр дахь биеийн ажил эхний удаагийнхаас ялгаатай ч Тэдний эх сурвалж ав адилхан биш гэдгийг энэ нь нотолдоггүй. Тэдний эх сурвалж адил эсэх нь Тэдний гадаад бүрхүүлээс биш, харин махбодоор хийгддэг ажлын шинж чанараас хамаардаг. Өөрийнхөө ажлын гурван үе шатны явцад Бурхан хоёр удаа бие махбодтой болсон ба хоёуланд нь бие махбодтой болсон Бурханы ажил шинэ эрин үеийг нээж, шинэ ажлыг эхлүүлдэг; ингэж бие махбодтой болсон нь нэг нэгнээ харилцан нөхдөг. Энэ хоёр махбод үнэндээ нэг эх сурвалжаас ирсэн гэдгийг хүний нүдээр танин мэдэх боломжгүй юм. Энэ нь хүний нүдний юм уу хүний оюун ухааны чадвараас хэтийдсэн зүйл гэдгийг хэлэх нь илүүц билээ. Гэхдээ мөн чанартаа бол Тэд адилхан, учир нь Тэдний ажил нэгэн Сүнснээс үүсдэг. Бурханы махбод болсон хоёр бие адилхан эх сурвалжаас гарч ирсэн эсэхийг Тэдний төрсөн эрин үе, төрсөн газраар юм уу, эсвэл тиймэрхүү бусад хүчин зүйлээр дүгнэж болохгүй, харин Тэдний илэрхийлсэн бурханлаг ажлаар л дүгнэж болно. Бурханы махбод болсон хоёр дахь бие нь Есүсийн хийсэн ажлын алийг ч хийдэггүй, учир нь Бурханы ажил тогтсон заншлыг мөрддөггүй, харин тухай бүрдээ шинэ зам нээдэг. Бурханы махбод болсон хоёр дахь бие нь хүмүүсийн оюун санаан дахь эхний махбодын талаарх сэтгэгдлийг гүнзгийрүүлж, бэхжүүлэх гэж зорьдоггүй, харин үүний дутууг нөхөж, төгс болгож, Бурханы талаарх хүний мэдлэгийг гүнзгийрүүлж, хүмүүсийн зүрх сэтгэлд оршдог бүх дүрмийг эвдэж, тэдний зүрх сэтгэл дэх Бурханы эндүү ташаа төрхийг арилгахаар зорьдог. Бурханы ажлын аль ч тусгаар үе шат нь хүнд Бурханы талаарх бүрэн гүйцэд мэдлэгийг өгч чадахгүй; үе шат бүр нь бүхэл биш, зөвхөн нэг хэсэг мэдлэгийг л өгдөг гэж хэлж болно. Хэдийгээр Бурхан Өөрийн зан чанарыг бүрэн илэрхийлсэн ч хүний ойлгох чадвар хязгаарлагдмал учраас Бурханы талаарх мэдлэг нь хагас хугас хэвээр үлддэг. Хүний хэлийг ашиглаад Бурханы зан чанарыг бүхэлд нь илэрхийлэх боломжгүй; түүнчлэн, Түүний ажлын ганц үе шат Бурханыг бүрэн илэрхийлж яахан чадах билээ? Тэр Өөрийн хэвийн хүн чанарын халхавч дор махбодоор ажилладаг ба хүн Түүнийг бие махбодын бүрхүүлээр нь биш, харин бурханлаг чанарын илэрхийллээр нь л мэдэж болно. Олон янзын ажлаар нь дамжуулан Өөрийг нь мэдэх боломжийг хүнд олгохын тулд Бурхан махбодод ирсэн бөгөөд Түүний ажлын ямар ч хоёр үе шат адилхан биш юм. Зөвхөн ийм маягаар л хүн махбод дахь Бурханы ажлын талаар ганц талд хязгаарлагдаагүй, бүрэн дүүрэн мэдлэгтэй болж чадна. Хэдийгээр Бурханы махбод болсон хоёр биеийн ажил ялгаатай байдаг ч махбодын мөн чанар ба Тэдний ажлын эх сурвалж нь ижил; Тэд ердөө л ажлын хоёр өөр үе шатыг хэрэгжүүлэхийн тулд оршдог, мөн хоёр өөр эрин үед гарч ирдэг. Ямартай ч Бурханы махбод болсон биес нь нэгэн адил мөн чанар болон нэгэн адил гарал үүсэлтэй байдаг—энэ бол хэний ч үгүйсгэж чадахгүй үнэн билээ.

БУРХАНЫ АЖИЛ БА ХҮНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Хүмүүсийн дундах Бурханы ажлыг хүнээс салгах аргагүй, учир нь хүн энэ ажлын бай бөгөөд Бурханы бүтээл дотроос Бурханд гэрчлэл хийж чадах цорын ганц бүтээл юм. Хүний амьдрал болон хүний бүх үйл ажиллагааг Бурханаас салгах аргагүй, бүгдийг нь Бурханы гар хянадаг бөгөөд нэг ч хүн Бурханаас тусгаар оршиж чадахгүй гэж ч хэлж болно. Энэ нь бодит баримт тул үүнийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Бурханы хийдэг бүхэн хүн төрөлхтний тусын тулд байдаг бөгөөд Сатаны заль мэхийн эсрэг чиглэдэг. Хүнд хэрэгтэй бүхэн Бурханаас ирдэг, Бурхан бол хүний амийн эх сурвалж билээ. Тиймээс хүн Бурханаас салж ердөө чаддаггүй. Цаашлаад Бурханд ч хүнээс салах санаа хэзээ ч байгаагүй. Бурханы хийдэг ажил бүх хүн төрөлхтний төлөө байдаг бөгөөд бодол нь үргэлжид сайн байдаг. Тэгвэл хүний хувьд, Бурханы ажил болон Бурханы бодлын (өөрөөр хэлбэл, Бурханы хүслийн) аль аль нь хүний мэдэх ёстой “үзэгдэл” юм. Ийм үзэгдэл нь бас Бурханы удирдлага бөгөөд хүний хийж чадахгүй ажил билээ. Ажлынхаа явцад хүнд Бурханы тавьдаг шаардлагыг хүний “хэрэгжүүлэлт” гэж нэрлэдэг. Үзэгдэл бол Бурханы Өөрийн ажил буюу хүн төрөлхтний төлөөх Түүний хүсэл, Түүний ажлын зорилго, ач холбогдол билээ. Үзэгдлийг бас удирдлагын нэг хэсэг гэж болно, учир нь энэхүү удирдлага бол Бурханы ажил бөгөөд хүнд чиглэдэг, энэ нь хүмүүсийн дунд Бурханы хийдэг ажил гэсэн үг юм. Энэ ажил бол хүн Бурханыг мэдэж авах нотолгоо болон зам бөгөөд хүний хувьд туйлын чухал. Хэрвээ Бурханы ажлын талаарх мэдлэгт анхаарал хандуулахын оронд хүмүүс, Бурханд итгэх итгэлийн тухай хоосон сургаал болон чухал биш аар саар зүйлсэд л анхаарлаа хандуулбал Бурханыг ердөө мэдэхгүйгээс гадна Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадахгүй. Бурханы ажил нь Бурханы талаарх хүний мэдлэгт асар тустай бөгөөд үүнийг үзэгдэл хэмээдэг. Эдгээр үзэгдэл бол Бурханы ажил, Бурханы хүсэл, түүнчлэн Бурханы ажлын зорилго болон ач холбогдол юм; эдгээр нь бүгд хүнд тустай. Хэрэгжүүлэлт гэдэг нь хүний хийх ёстой зүйл, Бурханыг дагадаг бүтээлүүдийн хийх ёстой зүйлийг хэлдэг бөгөөд энэ нь бас хүний үүрэг юм. Хүний хийх ёстой зүйл бол анхнаасаа хүний ойлгосон зүйл биш, харин Өөрийнхөө ажлын явцад хүнээс Бурханы шаарддаг зүйл юм. Бурханыг ажиллахын хэрээр эдгээр шаардлага аажмаар илүү гүн гүнзгий, илүү өндөр болдог. Жишээ нь, Хуулийн эрин үед хүн хуулийг дагах ёстой байсан, харин Нигүүлслийн эрин үед загалмай үүрэх ёстой байв. Хаанчлалын эрин үе бол өөр: Хүнд тавих шаардлага нь Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийнхээс илүү өндөр. Үзэгдэл илүү өндөр болохын хэрээр хүнд тавигдах шаардлага бүр ч их өндөр болж, илүү тодорхой, илүү бодитой болдог. Үүний адилаар, үзэгдэл ч бас улам бодитой болдог. Энэ олон бодит үзэгдэл хүнийг Бурханд дуулгавартай байхад туслахаар зогсохгүй, Бурханы талаарх хүний мэдлэгт тус болдог.

Өмнөх эрин үеүдтэй харьцуулахад Хаанчлалын эрин үеийн Бурханы ажил илүү бодитой, хүний мөн чанар болон түүний зан чанарын өөрчлөлтөд илүү их чиглэдэг

бөгөөд Өөрийг нь дагадаг бүх хүнд Бурханыг Өөрийг нь илүү их гэрчилж чаддаг. Өөрөөр хэлбэл, Хаанчлалын эрин үед Бурхан ажиллангаа, өмнөх аль ч үеийнхээс илүүтэйгээр хүнд Өөрийгөө харуулдаг бөгөөд энэ нь хүний мэдэх ёстой үзэгдэл өмнөх аль ч эрин үеийнхээс илүү өндөр байдаг гэсэн үг юм. Хүмүүсийн дундах Бурханы ажил урьд өмнө үзэгдээгүй нутаг дэвсгэрт орсон учраас Хаанчлалын эрин үед хүний мэдэж авдаг үзэгдэл нь бүх удирдлагын төлөвлөгөөн дэх хамгийн өндөр дээд нь билээ. Бурханы ажил урьд үзэгдээгүй нутаг дэвсгэрт орсон тул хүний мэдэх үзэгдэл бүх үзэгдлээс хамгийн өндөр дээд нь болсон ба үүнээс улбаалан хүний хэрэгжүүлэлт ч бас өмнөх аль ч эрин үеийнхээс илүү өндөр болсон, учир нь хүний хэрэгжүүлэлт үзэгдэлтэй зэрэгцэн өөрчлөгддөг бөгөөд үзэгдлийн төгс төгөлдөржилт нь ч бас хүнд тавигдах шаардлага төгс болсныг илтгэдэг. Бурханы бүх удирдлага зогсмогц хүний хэрэгжүүлэлт ч бас зогсох бөгөөд Бурханы ажил үгүй бол хүн өмнөх үеийн сургаалыг мөрдөхөөс өөр сонголтгүй, эсвэл ердөө хаашаа ч хандах аргагүй байх болно. Шинэ үзэгдэлгүйгээр хүний шинэ хэрэгжүүлэлт гэж байхгүй; бүрэн гүйцэд үзэгдэлгүйгээр хүний төгс хэрэгжүүлэлт гэж байхгүй; илүү өндөр үзэгдэлгүйгээр хүний илүү өндөр хэрэгжүүлэлт гэж байхгүй байх болно. Хүний хэрэгжүүлэлт Бурханы мөрийн хамтаар өөрчлөгддөгийн адилаар хүний мэдлэг, туршлага ч бас Бурханы ажилтай хамт өөрчлөгддөг. Хүн хэчнээн чадварлаг байх нь хамаагүй Бурханаас салшгүй хэвээр бөгөөд Бурхан хормын төдийд л ажиллахаа больсон бол Түүний уур хилэнгээс болж хүн нэн даруй үхэх байв. Хүний мэдлэг өнөөдөр хэчнээн өндөр байх нь хамаагүй, туршлага нь хэчнээн гүн гүнзгий байх нь хамаагүй хүн Бурханы ажлаас салшгүй учраас түүнд бардамнах зүйл юу ч үгүй—учир нь хүний хэрэгжүүлэлт болон Бурханд итгэх итгэлээсээ эрж хайх ёстой зүйл үзэгдлээс салшгүй билээ. Бурханы ажил бүрд хүний мэдэх ёстой үзэгдэл байдаг ба үүнийг дагаад хүнд тавьдаг зохих шаардлагууд гэж бий. Эдгээр үзэгдлийг суурь болгохгүйгээр хүн ердөө хэрэгжүүлж ч чадахгүй, мөн Бурханыг тууштай дагаж ч чадахгүй. Хэрвээ хүн Бурханыг мэддэггүй, эсвэл Бурханы хүслийг ойлгодоггүй бол хийдэг бүхэн нь хий дэмий болж, Бурханы сайшаалыг хүртэж чадахгүй. Хүн хэчнээн их билиг авьяастай байх нь хамаагүй, Бурханы ажлаас болон Бурханы удирдамжаас мөн л салшгүй. Хүний үйлдэл хэчнээн сайн байх нь, эсвэл тэд хэчнээн олон үйлдэл хийх нь хамаагүй Бурханы ажлыг орлож мөн л чадахгүй. Тиймээс ямар ч нөхцөл байдалд хүний хэрэгжүүлэлт үзэгдлээс салшгүй. Шинэ үзэгдлийг хүлээж авдаггүй хүмүүст шинэ хэрэгжүүлэлт байдаггүй. Тэд хоосон сургаалыг баримталж, үхмэл хуулийг мөрддөг учраас хэрэгжүүлэлт нь үнэнтэй ямар ч холбоогүй байдаг; тэдэнд ямар ч шинэ үзэгдэл байдаггүй, үүний үр дүнд тэд шинэ эрин үеийн юуг ч хэрэгжүүлдэггүй. Тэд үзэгдлийг алдсан, тэгснээрээ бас Ариун Сүнсний ажлыг алдаж, үнэнийг алдсан. Үнэнгүй хүмүүс бол утгагүй байдлын үр сад, Сатаны биелэл юм. Хүн ямар төрлийн хүн байх нь хамаагүй, Бурханы ажлын үзэгдэлгүйгээр байж чадахгүй, мөн Ариун Сүнстэй хамт биш бол байж чадахгүй; хүн үзэгдлийг алдмагцаа Үхэгсдийн оронд унаж, харанхуйд амьдардаг. Үзэгдэлгүй хүмүүс бол

Бурханыг мунхгаар дагагсад, Ариун Сүнсний ажилгүй хүмүүс бөгөөд тамд амьдарч байгаа. Ийм хүмүүс үнэнийг эрэлхийлдэггүй, харин оронд нь Бурханы нэрийг хаяг пайз адил өлгөдөг. Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, бие махбодтой болсон Бурханыг мэддэггүй, Бурханы бүхий л удирдлага дахь ажлын гурван үе шатыг мэддэггүй хүмүүс үзэгдлийг мэддэггүй тул үнэнгүй хүмүүс юм. Тэгвэл үнэнийг эзэмшээгүй хүмүүс бүгд мууг үйлдэгсэд биш гэж үү? Үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг, Бурханы талаарх мэдлэгийг эрж хайхыг хүсдэг, Бурхантай үнэхээр хамтран ажилладаг хүмүүс бол үзэгдлийг үндэс сууриа болгодог хүмүүс мөн. Тэд Бурхантай хамтран ажилладаг учраас Бурханы сайшаалыг хүртдэг бөгөөд хүний хэрэгжүүлэх ёстой зүйл бол энэхүү хамтын ажиллагаа юм.

Үзэгдэлд хэрэгжүүлэлтийн олон зам агуулагддаг. Хүнд тавьсан бодитой шаардлагууд нь ч бас үзэгдэл дотор агуулагддаг, хүний мэдэх ёстой Бурханы ажил ч бас агуулагддаг. Өнгөрсөн үед янз бүрийн газарт зохион байгуулагдаж байсан онцгой цуглаан юм уу томоохон цуглааны үеэр хэрэгжүүлэлтийн замын зөвхөн нэг талын тухай л ярьдаг байсан. Ийм хэрэгжүүлэлт нь Нигүүлслийн эрин үед хэрэгжүүлэх ёстой зүйл байсан бөгөөд Бурханы талаарх мэдлэгтэй бараг холбоогүй байсан, учир нь Нигүүлслийн эрин үеийн үзэгдэл нь зөвхөн Есүсийн цовдлолын үзэгдэл байсан ба өөр илүү агуу үзэгдэл байгаагүй. Хүн цовдлолоор дамжуулан хүн төрөлхтнийг золин аварсан Түүний ажлаас илүүг мэдэх учиргүй байсан тул Нигүүлслийн эрин үед хүний мэдвэл зохих өөр үзэгдэл байгаагүй юм. Ийм маягаар хүн Бурханы талаар хомсхон мэдлэгтэй байсан бөгөөд Есүсийн хайр, энэрлийн тухай мэдлэгээс гадна түүний хэрэгжүүлэх хэдхэн энгийн, өчүүхэн зүйлс буюу өнөөдрийнхөөс асар хол зөрүүтэй зүйл байдаг байв. Өнгөрсөн үед цугларалт нь ямар ч хэлбэртэй байсан бай, хүн Бурханы ажлын талаарх бодитой мэдлэгийг ярих чадваргүй байсан, тэр ч байтугай хүний орох хамгийн тохиромжтой хэрэгжүүлэлтийн зам аль болохыг хэн ч тодорхой хэлж чадаагүй. Хүн хүлээцтэй, тэвчээртэй байдлын сууринд хэдхэн энгийн зүйл нэмсэн төдий; түүний хэрэгжүүлэлтийн мөн чанарт ердөө ямар ч өөрчлөлт байгаагүй, учир нь нэг эрин үе дотор Бурхан ямар ч шинэлэг ажил хийгээгүй, хүнд тавьсан цорын ганц шаардлага нь тэвчээртэй, хүлээцтэй байдал, эсвэл загалмай үүрэх явдал байсан юм. Ийм хэрэгжүүлэлтээс гадна, Есүсийн цовдлолоос өөр илүү өндөр үзэгдэл байгаагүй. Урьд нь Бурхан асар их ажил хийгээгүй учраас, хүнд зөвхөн хязгаарлагдмал шаардлага тавьсан учраас өөр үзэгдлүүдийн тухай огт дурдаагүй. Ийм маягаар хүн юу ч хийсэн бай, хүний хэрэгжүүлэх цөөн хэдэн энгийн, өнгөц зүйлс бүхий эдгээр хязгаарыг давж чадаагүй. Өнөөдөр, илүү их ажил хийгдсэн, Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийнхээс хэд дахин их ажил хийгдсэн учраас Би өөр үзэгдлүүдийн тухай ярьдаг. Хүнд тавих шаардлага ч бас өмнөх эрин үеүдийнхээс хэд дахин өндөр болсон. Хэрвээ хүн энэ ажлыг бүхэлд нь мэдэж чадахгүй бол энэ ажил асар их ач холбогдолтой байхгүй; хэрвээ хүн үүнд насан туршийн хичээл чармайлтаа зориулахгүй бол энэ ажлыг бүрэн мэдэхэд хэцүү байх болно гэж хэлж

болох юм. Байлдан дагуулалтын ажилд дан ганц хэрэгжүүлэлтийн замын талаар яривал хүнийг байлдан дагуулах боломжгүй. Хүнд ямар ч шаардлага тавихгүйгээр зөвхөн үзэгдлийн талаар яривал хүнийг байлдан дагуулах бас л боломжгүй. Хэрэгжүүлэлтийн замаас өөр зүйл ярихгүй байх аваас хүний амин газрыг цохиж, хүний үзлийг сарниах боломжгүй байх тул хүнийг бүрэн байлдан дагуулах ч бас боломжгүй байх болно. Үзэгдэл бол хүнийг байлдан дагуулах гол хэрэгсэл юм, гэхдээ үзэгдлээс гадна ямар ч хэрэгжүүлэлтийн зам байгаагүй бол хүн дагах аргагүй, тэр ч бүү хэл орох арга барилгүй байх байсан. Энэ нь эхнээсээ эцэс хүртлээ Бурханы ажлын зарчим байсаар ирсэн: Үзэгдэлд хэрэгжүүлж болох зүйл байдаг бөгөөд ийм хэрэгжүүлэлт дээр нэмээд үзэгдэл ч бас байдаг. Хүний амь болон зан чанарын аль алинд нь гардаг өөрчлөлтийн түвшин нь үзэгдэл дэх өөрчлөлтийг дагалддаг. Хүн зөвхөн өөрийн хүчин чармайлтад найдсан бол ямар нэгэн өндөр түвшний өөрчлөлтөд хүрэх боломжгүй байх байсан. Үзэгдэл нь Бурханы Өөрийн ажил болон Бурханы удирдлагын тухай өгүүлдэг. Хэрэгжүүлэлт гэдэг нь хүний хэрэгжүүлэлтийн зам болон хүний оршин тогтнолын замыг хэлдэг; Бурханы бүх удирдлагад, үзэгдэл болон хэрэгжүүлэлтийн хоорондох харилцаа нь Бурхан, хүн хоёрын хоорондох харилцаа юм. Хэрвээ үзэгдлүүдийг хасах юм уу хэрэгжүүлэлтийг дурдахгүйгээр тэдгээрийн талаар яривал, эсвэл зөвхөн үзэгдэл л байгаад хүний хэрэгжүүлэлтийг арилгасан бол тийм зүйлийг Бурханы удирдлага гэж үзэж болохгүй, Бурханы ажил хүн төрөлхтний төлөө байдаг гэж хэлж бүр ч болохгүй; ийм маягаар хүний үүрэг үгүй болоод зогсохгүй Бурханы ажлын зорилго үгүйсгэгдэх болно. Хэрвээ эхнээсээ эцэс хүртлээ хүн Бурханы ямар нэгэн ажлын оролцоогүйгээр зөвхөн хэрэгжүүлэх шаардлагатай байсан бол, түүнчлэн хүнд Бурханы ажлыг мэдэх шаардлага байгаагүй бол ийм ажлыг Бурханы удирдлага гэж нэрлэж бүр ч болохгүй. Хэрвээ хүн Бурханыг мэдээгүй, Бурханы хүслийг мэдээгүй бөгөөд өөрийн хэрэгжүүлэлтийг тодорхойгүй, хийсвэр байдлаар, сохроор хэрэгжүүлдэг байсан бол хэзээ ч бүрэн шаардлага хангасан бүтээл болохгүй байх байлаа. Иймээс энэ хоёр зүйл хоёулаа зайлшгүй чухал юм. Хэрвээ зөвхөн Бурханы ажил байсан бол, өөрөөр хэлбэл, хүний хамтын ажиллагаа юм уу хэрэгжүүлэлт байхгүй зөвхөн үзэгдэл байсан бол ийм зүйлийг Бурханы удирдлага гэж нэрлэж болохгүй. Хэрвээ зөвхөн хүний хэрэгжүүлэлт болон оролт л байсан бол хүний орсон зам хэр өндөр байх нь хамаагүй, энэ ч бас зөвшөөрөхийн аргагүй юм. Хүний оролт ажил болон үзэгдэлтэй зэрэгцэн аажмаар өөрчлөгдөх ёстой; үүнийг дур зоргоороо өөрчилж болохгүй. Хүний хэрэгжүүлэлтийн зарчим чөлөөтэй, задгай биш, харин ч тодорхой хил хязгаар дотор байдаг. Ийм зарчим нь ажлын үзэгдэлтэй зэрэгцэн өөрчлөгддөг. Тиймээс Бурханы удирдлага нь эцэстээ Бурханы ажил болон хүний хэрэгжүүлэлтээс хамаардаг.

Удирдлагын ажил нь хүн төрөлхтнөөс л болж бий болсон, энэ нь хүн төрөлхтний оршин тогтнолоос л болж бий болсон гэсэн үг юм. Хүн төрөлхтнөөс өмнө буюу анх тэнгэр, газар болон бүх зүйл бүтээгдэх үед ямар ч удирдлага байгаагүй. Хэрвээ

Бурханы бүх ажилд хүнд ашиг тустай хэрэгжүүлэлт байгаагүй, өөрөөр хэлбэл, хэрвээ Бурхан завхарсан хүн төрөлхтөнд тохирсон шаардлага тавиагүй бол (хэрвээ Бурханы хийсэн ажилд хүний хэрэгжүүлэлтэд тохирох ямар ч зам байгаагүй бол) энэ ажлыг Бурханы удирдлага гэж нэрлэж болохгүй байх байв. Хэрвээ Бурханы бүхий л ажил хэрхэн хэрэгжүүлэх талаар завхарсан хүн төрөлхтөнд л яриад, Бурхан Өөрийн ямар ч үйл хэргийг явуулаагүй, бүхнийг чадагч чадвар болоод мэргэн ухааныхаа өчүүхэн хэсгийг ч үзүүлээгүй бол Бурханы хүнд тавих шаардлага хэр өндөр байх нь хамаагүй, Бурхан хүмүүсийн дунд хэр удаан амьдарсан нь хамаагүй, хүн Бурханы зан чанарын юуг ч мэдэхгүй байх байсан; хэрвээ тийм байсан бол энэ төрлийн ажлыг Бурханы удирдлага гэж нэрлэхэд бүр ч зохихгүй. Энгийнээр хэлбэл, Бурханы удирдлагын ажил бол Бурханы хийдэг ажил бөгөөд Бурханаар авхуулсан хүмүүсийн Бурханы удирдамж дор хийдэг бүх ажил юм. Ийм ажлыг удирдлага гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн дундах Бурханы ажил, мөн Түүнийг дагадаг бүх хүмүүсийн хамтын ажиллагааг нийтэд нь удирдлага гэж нэрлэдэг. Энд, Бурханы ажлыг үзэгдэл, харин хүний хамтын ажиллагааг хэрэгжүүлэлт гэж нэрлэдэг. Бурханы ажил өндөр байх тусам (өөрөөр хэлбэл, үзэгдэл өндөр байх тусам) Бурханы зан чанар хүнд улам ил болдог бөгөөд хүний үзэлтэй нийцэхгүй байх тусам хүний хэрэгжүүлэлт болон хамтын ажиллагаа төдий чинээ өндөр байдаг. Хүнд тавих шаардлага өндөр байх тусам Бурханы ажил хүний үзэлтэй төдий чинээ зөрөлддөг, үүнээс улбаалан хүний шалгалт, хүнээс шаарддаг стандарт ч бас өндөр болдог. Энэ ажлын эцэст бүх үзэгдэл бүрэн төгс болж, хүний хэрэгжүүлэх шаардлагатай зүйлс төгс төгөлдрийн оргилд хүрсэн байх болно. Энэ нь бас бүгд төрлийнхөө дагуу ангилагдах үе байх болно, учир нь хүний мэдэх шаардлагатай зүйлсийг хүнд харуулсан байх болно. Иймээс үзэгдэл оргилдоо хүрч, ажил ч дуусах тийшээ хандах үед хүний хэрэгжүүлэлт ч бас дээд цэгтээ хүрсэн байх болно. Хүний хэрэгжүүлэлт Бурханы ажилд үндэслэдэг, харин Бурханы удирдлага нь хүний хэрэгжүүлэлт болон хамтын ажиллагааны ачаар л бүрэн илэрхийлэгддэг. Хүн бол Бурханы ажлын үзмэр, Бурханы бүх удирдлагын ажлын бай, бас Бурханы бүхий л удирдлагын үр дүн юм. Хэрвээ Бурхан хүний хамтын ажиллагаагүйгээр ганцаараа ажилласан бол Түүний бүх ажлын биелэлт болох зүйл юу ч байхгүй байх байсан ба ийм маягаар Бурханы удирдлага өчүүхэн төдий ч ач холбогдолгүй байх байлаа. Бурханы ажлаас гадна, Өөрийнх нь ажлыг илэрхийлж, бүхнийг чадагч байдал болон мэргэн ухааныг нь нотлоход тохирох байг Бурхан сонгосноор л удирдлагынхаа зорилгыг биелүүлж, энэ бүх ажлыг ашиглан Сатаныг бүрэн ялах зорилгодоо хүрч чадна. Тиймээс хүн бол Бурханы удирдлагын ажлын салшгүй чухал хэсэг бөгөөд гагцхүү хүн л Бурханы удирдлагыг үр өгөөжтэй болгож, эцсийн зорилгыг нь биелүүлж чадна; хүнээс өөр ямар ч амьд зүйл ийм үүрэг гүйцэтгэж чадахгүй. Хэрвээ хүн удирдлагын ажлын жинхэнэ биелэлт болно гэвэл завхарсан хүн төрөлхтний дуулгаваргүй байдлыг бүрэн арилгах ёстой. Хүнд өөр өөр цаг үед тохирох хэрэгжүүлэлт өгөгдөж, Бурхан хүмүүсийн дунд харгалзах

ажлыг гүйцэтгэхийг энэ нь шаарддаг. Зөвхөн ийм маягаар л удирдлагын ажлын биелэлт болох бүлэг хүмүүсийг эцэстээ олж авна. Хүмүүсийн дундах Бурханы ажил дан ганц Бурханы ажлаар дамжуулан Бурханд Өөрт нь гэрчлэл хийж чадахгүй; Түүний ажилд тохирох амьд хүмүүс ийм гэрчлэлд бас шаардлагатай. Бурхан эхлээд энэ хүмүүс дээр ажиллаж, тэднээр дамжуулан Түүний ажил илэрхийлэгдэж, улмаар бүтээгдсэн зүйлсийн дунд Түүний ийм гэрчлэл хийгдэх болно. Ингээд Бурхан ажлынхаа зорилгод хүрсэн байх болно. Бурхан бүх бүтээгдсэн зүйлийн дунд Өөрийгөө шууд гэрчилж чадахгүй учраас Сатаныг ялахын тулд ганцаараа ажилладаггүй. Хэрэв Тэр ганцаараа ажилладаг байсан бол хүнийг бүрэн үнэмшүүлэх боломжгүй байх тул хүнийг байлдан дагуулахын тулд Бурхан түүн дээр ажиллах ёстой бөгөөд тэгж байж л бүх бүтээгдсэн зүйлийн дундах гэрчлэлийг олж авч чадна. Хэрвээ Бурхан ганцаараа ажиллаж, хүний хамтын ажиллагаа гэж байхгүй, эсвэл хүн хамтран ажиллах шаардлагагүй байсан бол хүн Бурханы зан чанарыг хэзээ ч мэдэж чадахгүй, Бурханы хүслийг үүрд мэдэхгүй байх байсан; тэгвэл Бурханы ажлыг Бурханы удирдлагын ажил гэж нэрлэж болохгүй байх байсан юм. Хүн Бурханы ажлыг ойлголгүйгээр, өөрөө л чармайж, эрж хайж, шаргуу ажиллах байсан бол дүрсгүйтэж томоогүйтэх байв. Ариун Сүнсний ажилгүйгээр, хүний хийдэг зүйл Сатаных бөгөөд тэрээр тэрслүү, мууг үйлдэгч юм; Сатан завхарсан хүн төрөлхтний хийдэг бүхнээс харагддаг ба Бурханд нийцэлтэй юу ч байдаггүй, хүний хийдэг бүхэн Сатаны илрэл юм. Яригдсан бүхэнд үзэгдэл болон хэрэгжүүлэлтгүй юм гэж юу ч байхгүй. Үзэгдлийн суурин дээр хүн хэрэгжүүлэлт болон дуулгавартай байдлын замыг олж авдаг, ингэснээр үзлээ хойш тавьж, өмнө нь эзэмшээгүй зүйлсээ олж авч болох юм. Бурхан хүнээс Өөртэй нь хамтран ажиллахыг, Өөрийнх нь шаардлагад бүрэн захирагдахыг шаарддаг бөгөөд Бурханы Өөрийн хийсэн ажлыг харж, Бурханы төгс хүчийг мэдэрч, Бурханы зан чанарыг мэдэхийг хүн шаарддаг. Эдгээр нь товчхондоо Бурханы удирдлага юм. Бурханы хүнтэй нэгдэх нэгдэл нь удирдлага бөгөөд энэ нь хамгийн агуу удирдлага билээ.

Үзэгдлийг агуулдаг зүйл нь үндсэндээ Бурханы Өөрийн ажлыг хэлдэг бөгөөд хэрэгжүүлэлттэй холбоотой зүйл нь хүний хийх ёстой зүйлийг агуулдаг, Бурхантай ямар ч хамаагүй байдаг. Бурханы ажлыг Бурхан Өөрөө гүйцэтгэдэг, хүний хэрэгжүүлэлтийг хүн өөрөө биелүүлдэг. Бурханы Өөрийн хийх ёстой ажлыг хүн хийх хэрэггүй, хүний хэрэгжүүлэх ёстой зүйл Бурханд хамаагүй. Бурханы ажил бол Түүний Өөрийн үйлчлэл бөгөөд хүнтэй ямар ч холбоогүй. Энэ ажлыг хүн хийх хэрэггүй, цаашлаад Бурханы хийдэг ажлыг хүн хийх чадваргүй. Хүний хэрэгжүүлэх шаардлагатай зүйлийг хүн хийх ёстой бөгөөд амиа золиослох ч бай, гэрчлэлд зогсоохын тулд өөрийг нь Сатанд өгсөн ч бай—эдгээрийг бүгдийг нь хүн гүйцэлдүүлэх ёстой. Өөрийнхөө хийх учиртай бүх ажлыг Бурхан Өөрөө хийдэг, харин хүний хийх ёстой ажлыг хүнд харуулж, үлдсэн ажлыг нь хүнээр хийлгэхээр үлдээдэг. Бурхан нэмэлт ажил хийдэггүй. Тэр зөвхөн Өөрийн үйлчлэл дэх ажлыг л хийж, хүнд замыг үзүүлж, замыг нээх ажил л хийдэг ба замыг засах ажил хийдэггүй;

үүнийг бүх хүн ойлгох ёстой. Үнэнийг хэрэгжүүлэх гэдэг нь Бурханы үгийг хэрэгжүүлэх гэсэн үг, энэ бүхэн нь хүний үүрэг, хүний хийх ёстой зүйл бөгөөд Бурхантай ямар ч хамаагүй. Хэрэв хүн Бурханаас, хүнтэй адилаар үнэн дотор цэвэршүүлэлт, тарчлаан амсахыг шаардвал хүн дуулгаваргүй байгаа хэрэг. Бурханы ажил бол Өөрийн үйлчлэлийг гүйцэлдүүлэх, харин хүний үүрэг бол Бурханы бүх удирдамжийг ямар ч эсэргүүцэлгүйгээр дуулгавартай дагах явдал юм. Бурханы ажиллаж, амьдардаг байдлаас үл хамааран хүн биелүүлэх ёстой зүйлдээ хүрэх л ёстой. Бурхан Өөрөө л хүнд шаардлага тавьж чадна, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө л хүнд шаардлага тавихад тохирдог. Хүнд ямар ч сонголт байх ёсгүй бөгөөд бүрэн захирагдаж, хэрэгжүүлэхээс өөрийг хийх ёсгүй; энэ бол хүний эзэмших ёстой эрүүл ухаан юм. Бурханы Өөрийн хийх ёстой ажил дуусмагц хүн алхам алхмаар үүнийг туулах шаардлагатай. Эцэст нь Бурханы бүх удирдлага дууссан байх үед хүн Бурханы шаарддаг зүйлийг мөн л хийгээгүй байвал шийтгүүлэх ёстой. Хэрэв хүн Бурханы шаардлагыг биелүүлдэггүй бол энэ нь хүний дуулгаваргүй байдлаас болж байгаа юм; энэ нь Бурхан ажлаа хангалттай сайн хийгээгүй гэсэн үг. Бурханы үгийг хэрэгжүүлж, Бурханы шаардлагыг биелүүлж, үнэнч байж, үүргээ биелүүлж чаддаггүй бүх хүн шийтгүүлнэ. Өнөөдөр та нараас шаардаг зүйлс нэмэлт шаардлага биш, харин хүний үүрэг, бүх хүний биелүүлэх ёстой үүрэг юм. Хэрэв та нар үүргээ ч гүйцэтгэж чадахгүй, үүргээ сайн гүйцэтгэж чадахгүй бол өөрсдөдөө төвөг удаж байгаа бус уу? Та нар үхлийг өөртөө татаж байгаа бус уу? Та нар яаж ирээдүй, хэтийн зүйлсийг хүлээж чадаж байна вэ? Бурханы ажил хүн төрөлхтний төлөө хийгддэг, харин хүний хамтын ажиллагаа Бурханы удирдлагын төлөө байдаг. Бурхан хийх ёстой бүхнээ хийсний дараа хүн биеэ дайчлан хэрэгжүүлж, Бурхантай хамтран ажиллах шаардлагатай. Бурханы ажилд хүн хичээл зүтгэлээ гамналгүй, үнэнч зангаа зориулах ёстой, мөн тоо томшгүй олон үзэлд баригдаж, эсвэл идэвхгүйгээр үхлээ хүлээн суух ёсгүй. Бурхан Өөрийгөө хүний төлөө золиосолж чадна, тэгвэл хүн яагаад Бурханд үнэнч байдлаа өргөж болохгүй гэж? Бурхан хүнд хоёргүй сэтгэлээр ханддаг атал хүн яагаад өчүүхэн ч болов хамтран ажиллаж болохгүй гэж? Бурхан хүн төрөлхтний төлөө ажилладаг атал хүн яагаад Бурханы удирдлагын төлөө зарим нэг үүргээ биелүүлж болохгүй гэж? Бурханы ажил энэ хүртэл ирчихээд байхад та нар юу ч хийхгүй харсаар, сонссон ч хөдлөхгүй суусаар. Ийм хүмүүс мөхлийн бай биш гэж үү? Бурхан аль хэдийн Өөрийн бүх зүйлийг хүнд зориулсан, гэтэл яагаад хүн өнөөдөр өөрийн үүргийг үнэн сэтгэлээсээ гүйцэтгэж чадахгүй байна вэ? Бурханы хувьд, Түүний ажил эн тэргүүний зүйл бөгөөд Түүний удирдлагын ажил хамгийн чухал нь билээ. Хүний хувьд, Бурханы үгийг хэрэгжүүлж, Бурханы шаардлагыг биелүүлэх нь эн тэргүүний зүйл. Үүнийг та нар бүгд ойлгох учиртай. Та нарт хэлсэн үг мөн чанарын чинь угт хүрч, Бурханы ажил урьд өмнө байгаагүй хүрээнд орсон. Олон хүн энэ замын үнэн, худлыг мөн л ойлгодоггүй; тэд хүлээсээр, харсаар, өөрсдийн үүргийг үл биелүүлдэг. Үүний оронд тэд Бурханы үг, үйлдэл бүрийг шалгаж, юу

идэж, юу өмсдөгт нь анхаарал хандуулдаг ба тэдний үзэл улам бүр ноцтой болдог. Ийм хүмүүс дэмий санаа зовж байгаа хэрэг биш гэж үү? Ийм хүмүүс яаж Бурханыг эрж хайдаг хүмүүс байж чадах юм бэ? Тэд яаж Бурханд захирагддаг санаа зорилготой хүмүүс болж чадах билээ? Тэд өөрсдийн үнэнч байдал болоод үүргийг умартаж, оронд нь Бурхан хаа байгаад хамаг анхаарлаа хандуулдаг. Тэд үнэхээр зэвүү хүргэм! Хэрэв хүн ойлгох учиртай бүхнээ ойлгож, хэрэгжүүлэх учиртай бүхнээ хэрэгжүүлсэн бол Бурхан Өөрийн ерөөлийг хүнд гарцаагүй хайрлана, учир нь хүнээс Түүний шаарддаг зүйл бол хүний үүрэг бөгөөд хүний хийх ёстой зүйл билээ. Хэрэв хүн ойлгох учиртай зүйлээ ойлгож, хэрэгжүүлэх учиртай зүйлээ хэрэгжүүлж чадахгүй бол шийтгүүлнэ. Ийм хүмүүс илт эсэргүүцэх зүйл хийдэггүй байлаа ч гэсэн, Бурхантай хамтран ажилладаггүй хүмүүс Бурханд дайсагнадаг бөгөөд шинэ ажлыг хүлээн авдаггүй хүмүүс үүнийг эсэргүүцэж байдаг. Бурханы шаардсан үнэнийг хэрэгжүүлдэггүй бүх хүн нь Ариун Сүнсний ажилд онцгой анхаарал хандуулдаг байсан ч гэсэн Бурханы үгийг дуулгавартай дагадаггүй, санаатайгаар эсэргүүцдэг хүмүүс юм. Бурханы үгийг дуулгавартай дагадаггүй, Бурханд захирагддаггүй хүмүүс бол тэрслүү агаад Бурханыг эсэргүүцдэг. Үүргээ биелүүлдэггүй хүмүүс бол Бурхантай хамтран ажилладаггүй хүмүүс бөгөөд Бурхантай хамтран ажилладаггүй хүмүүс бол Ариун Сүнсний ажлыг хүлээн авдаггүй хүмүүс билээ.

Бурханы ажил болоод Түүний удирдлага тодорхой цэгт хүрэх үед Түүний зүрх сэтгэлийн дагуу байдаг хүмүүс бүгд Түүний шаардлагыг биелүүлэх чадвартай байдаг. Бурхан Өөрийн стандартын дагуу, хүний хүрч чадах зүйлийн дагуу хүнд шаардлага тавьдаг. Өөрийн удирдлагын талаар ярихын сацуу Тэр бас хүний замыг зааж, амьд үлдэх замаар хүнийг хангадаг. Бурханы удирдлага болон хүний хэрэгжүүлэлт нь хоёулаа ажлын нэг үе шат бөгөөд нэгэн зэрэг явагддаг. Бурханы удирдлагын тухай яриа нь хүний зан чанарын өөрчлөлттэй холбоотой байдаг бол хүний хийх ёстой зүйл болоод хүний зан чанарын өөрчлөлтийн талаарх яриа Бурханы ажилтай хамаатай байдаг; энэ хоёрыг ямар ч үед салгахын аргагүй. Хүний хэрэгжүүлэлт алхам алхмаар өөрчлөгдөж байгаа. Учир нь Бурханы хүнд тавих шаардлага үргэлж өөрчлөгдөж, Бурханы ажил ч бас үргэлж өөрчлөгдөн, ахин дэвшиж байгаа. Хэрэв хүний хэрэгжүүлэлт хоосон сургаалд баригдсан хэвээр байвал хүнд Бурханы ажил болон удирдамж байхгүйг энэ нь нотолдог; хэрэв хүний хэрэгжүүлэлт хэзээ ч өөрчлөгдөж, гүнзгийрч байгаагүй бол энэ нь, хүний хэрэгжүүлэлт хүний хүслийн дагуу явагдсаны баталгаа бөгөөд үнэний хэрэгжүүлэлт биш юм; хэрэв хүн алхах замгүй бол тэр аль хэдийн Сатаны гарт унаж, Сатаны хяналтад орж, муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн гэсэн үг билээ. Хэрвээ хүний хэрэгжүүлэлт гүнзгийрэхгүй бол Бурханы ажил хөгжихгүй бөгөөд Бурханы ажилд ямар ч өөрчлөлт байхгүй бол хүний оролт зогсоно; энэ нь зайлшгүй. Бурханы бүх ажлын хугацаанд хэрвээ хүн үргэлж Еховагийн хуулийг мөрддөг байсан бол Бурханы ажил урагшлахгүй, бүхий л эрин үеийг төгсгөл болгох бүр ч боломжгүй байх байв. Хэрэв хүн үргэлж загалмайтай зууралдаж, тэвчээр, даруу байдлыг

хэрэгжүүлсэн бол Бурханы ажил үргэлжлэн урагшлах боломжгүй байх байлаа. Зөвхөн хуулийг сахиж, загалмайтай зууралдан, тэвчээр, даруу байдлыг хэрэгжүүлдэг хүмүүсийн дунд зургаан мянган жилийн удирдлагыг дуусгавар болгох ердөө боломжгүй. Харин Бурханыг мэддэг, Сатаны савраас мултарч, Сатаны нөлөөллөөс бүрэн ангижирсан эцсийн өдрүүдийн хүмүүсийн дунд Бурханы удирдлагын бүх ажил дуусна. Энэ бол Бурханы ажлын зайлшгүй чиглэл юм. Яагаад шашны чуулган дахь хүмүүсийн хэрэгжүүлэлтийг хоцрогдсон гэж хэлдэг вэ? Учир нь тэдний хэрэгжүүлдэг зүйл өнөөдрийн ажлаас тусдаа байдаг. Нигүүлслийн эрин үед тэдний хэрэгжүүлж байсан зүйл зөв байсан боловч эрин үе өнгөрч, Бурханы ажил өөрчлөгдөхийн хэрээр хэрэгжүүлэлт нь аажмаар хоцрогдсон билээ. Энэ нь шинэ ажил болон шинэ гэрлийн ард үлдсэн. Ариун Сүнсний ажил анхдагч сууриндаа үндэслэн хэд хэдэн алхмаар гүнзгийрсэн. Гэсэн ч тэр хүмүүс Бурханы ажлын анхны үе шатанд гацаж, хуучин хэрэгжүүлэлт, хуучин гэрэлтэй зууралдсаар байдаг. Бурханы ажил гурав юм уу таван жилийн дотор ихээхэн өөрчлөгдөж чадна, тэгвэл 2,000 жилийн хугацаанд бүр ч их өөрчлөгдөхгүй гэж үү? Хэрвээ хүнд шинэ гэрэл юм уу хэрэгжүүлэлт байхгүй бол Ариун Сүнсний ажилтай хөл нийлүүлээгүй байна гэсэн үг. Энэ бол хүний алдаа; урьд нь Ариун Сүнсний ажилтай байсан хүмүүс өнөөдөр хоцрогдсон хэрэгжүүлэлтийг мөрдсөөр байдгаас болж Бурханы шинэ ажлын оршин тогтнолыг үгүйсгэж болохгүй. Ариун Сүнсний ажил үргэлж урагшилж байдаг ба Ариун Сүнсний урсгалд байгаа бүх хүн ч бас алхам алхмаар гүнзгийрч, өөрчлөгдөж байх ёстой. Тэд ганцхан үе шатанд зогсох ёсгүй. Ариун Сүнсний ажлыг мэддэггүй хүмүүс л анхны ажлынх нь дунд үлддэг ба Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн авдаггүй. Дуулгаваргүй хүмүүс л Ариун Сүнсний ажлыг олж авах чадваргүй байх болно. Хэрвээ хүний хэрэгжүүлэлт Ариун Сүнсний шинэ ажилтай хөл нийлүүлдэггүй бол өнөөдрийн ажлаас гарцаагүй салсан байх бөгөөд өнөөдрийн ажилтай нийцэхгүй нь гарцаагүй. Ийм хоцрогдсон хүмүүс Бурханы хүслийг биелүүлж ердөө чадахгүй, эцэстээ Бурханы гэрчлэлд зогсох хүмүүс болж бүр ч чадахгүй. Түүнчлэн бүхий л удирдлагын ажил ийм бүлэг хүмүүсийн дунд дуусгавар болж чадахгүй. Нэгэнтээ Еховагийн хуулийг мөрддөг байсан хүмүүс, нэг үе загалмайн төлөө зовсон хүмүүсийн хувьд гэвэл, эцсийн өдрүүдийн ажлын үе шатыг хүлээн авч чадахгүй бол хийсэн бүхэн нь хий дэмий, хэрэггүй болно. Ариун Сүнсний ажлын хамгийн тодорхой илэрхийлэл нь амьдралтай ойрхон бөгөөд өнгөрсөнтэй зууралддаггүй. Өнөөдрийн ажилтай хөл нийлүүлээгүй, өнөөдрийн хэрэгжүүлэлтээс салсан хүмүүс бол Ариун Сүнсний ажлыг хүлээн авдаггүй, эсэргүүцдэг хүмүүс юм. Ийм хүмүүс Бурханы өнөөгийн ажлыг эсэргүүцдэг. Хэдий тэд өнгөрсөн үеийн гэрэлтэй зууралддаг ч Ариун Сүнсний ажлыг мэддэггүй хүмүүс гэдгийг нь үгүйсгэж болохгүй. Хүний хэрэгжүүлэлт дэх өөрчлөлт, өнгөрсөн болоод өнөөдрийн хэрэгжүүлэлтийн хоорондох ялгаа, өмнөх эрин үед хэрхэн хэрэгжүүлж байсан, өнөөдөр үүнийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар яагаад эхнээс нь дуустал ингэж их яриад байна вэ? Ариун Сүнсний ажил байнга урагшилдгаас болж хүний

хэрэгжүүлэлт дэх ийм хуваагдлыг үргэлж ярьдаг, тиймээс хүний хэрэгжүүлэлт ч бас байнга өөрчлөгдөх шаардлагатай. Хэрэв хүн нэг үе шатанд гацсан хэвээр үлдвэл Бурханы шинэ ажил болон шинэ гэрэлтэй хөл нийлүүлэх чадваргүйг энэ нь нотолдог; энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөө өөрчлөгдөөгүй гэдгийг нотолдоггүй. Ариун Сүнсний урсгалын гадна байгаа хүмүүс үргэлж өөрсдийнх нь зөв гэж боддог боловч үнэндээ тэдэн дээрх Бурханы ажил аль хэдийн зогссон ба Ариун Сүнсний ажил тэдэнд байдаггүй. Шинэ ажлаа гүйцэлдүүлэхээр Бурханы зорьдог өөр бүлэг хүмүүс буюу өөр бүлэг хүмүүс рүү Бурханы ажил аль хэдийн шилжсэн. Шашны хүмүүс Бурханы шинэ ажлыг хүлээн авах чадваргүй, өнгөрсөн үеийн хуучин ажилтай л зууралддаг учраас Бурхан тэр хүмүүсийг орхисон бөгөөд шинэ ажлыг нь хүлээн авдаг хүмүүс дээр энэхүү шинэ ажлаа хийдэг. Тэд бол Бурханы шинэ ажилд хамтран ажилладаг хүмүүс бөгөөд ийм маягаар л Түүний удирдлага гүйцэлдэж чадна. Бурханы удирдлага үргэлж урагшилж, хүний хэрэгжүүлэлт үргэлж илүү өндөрт өсөн дээшилж байдаг. Бурхан үргэлж ажиллаж байгаа ба хүнд үргэлж хэрэгцээ байдаг, тэгснээр хоёулаа оргилдоо хүрч, Бурхан хүн хоёр бүрэн нэгддэг. Энэ бол Бурханы ажлын биелэлтийн илэрхийлэл, Бурханы бүхий л удирдлагын эцсийн үр дүн юм.

Бурханы ажлын үе шат бүрд хүнд тавигддаг харгалзах шаардлагууд бас бий. Ариун Сүнсний урсгал доторх бүх хүн Ариун Сүнстэй хамт, Ариун Сүнсний сахилгажуулалттай байдаг, харин Ариун Сүнсний урсгалын гаднах хүмүүс Сатаны захиргаан дор, Ариун Сүнсний ямар ч ажилгүй байдаг. Ариун Сүнсний урсгалд байгаа хүмүүс бол Бурханы шинэ ажлыг хүлээн авч, Бурханы шинэ ажилд хамтран ажилладаг хүмүүс юм. Хэрвээ энэ урсгал доторх хүмүүс хамтран ажиллах чадваргүй, энэ хугацаанд Бурханы шаардсан үнэнийг хэрэгжүүлж чаддаггүй бол сахилгажуулагдан, цаанадаж Ариун Сүнсэнд хаягдах болно. Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн авдаг хүмүүс Ариун Сүнсний урсгал дотор амьдарч, Ариун Сүнсний халамж, хамгаалалтыг хүртэнэ. Үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүсийг Ариун Сүнс гэгээрүүлдэг бөгөөд үнэнийг хэрэгжүүлэх хүсэлгүй хүмүүсийг Ариун Сүнс сахилгажуулж, бүр шийтгэж ч болох юм. Ямар төрлийн хүн байхаас үл хамааран Ариун Сүнсний урсгалд л байгаа цагт, Өөрийнх нь нэрийн төлөө шинэ ажлыг нь хүлээн авдаг бүх хүний хувьд Бурхан хариуцлага үүрэх болно. Түүний нэрийг алдаршуулдаг, үгийг нь хэрэгжүүлэхийг хүсдэг хүмүүс Түүний ерөөлийг хүртэнэ; Түүнд дуулгаваргүй байж, Түүний үгийг хэрэгжүүлдэггүй хүмүүс Түүнээс шийтгэл хүртэнэ. Ариун Сүнсний урсгалд байгаа хүмүүс бол шинэ ажлыг хүлээн авдаг хүмүүс бөгөөд шинэ ажлыг хүлээн авсан тул Бурхантай зохих ёсоор хамтран ажиллах ёстой, мөн үүргээ биелүүлдэггүй босогчид болж болохгүй. Энэ бол хүнд Бурханы тавьдаг цорын ганц шаардлага юм. Харин шинэ ажлыг хүлээн авдаггүй хүмүүсийн хувьд бол өөр: Тэд Ариун Сүнсний урсгалын гадна байдаг, Ариун Сүнсний сахилгажуулалт, зэмлэл тэдэнд хамаагүй байдаг. Энэ хүмүүс бүхий л өдөржингөө махан бие, оюун санаан дотроо амьдарч, уураг тархиных нь дүн

шинжилгээ, судалгаанаас үүссэн хоосон сургаалын дагуу бүхнийг хийдэг. Энэ нь Ариун Сүнсний шинэ ажлын шаарддаг зүйл биш, Бурхантай хийх хамтын ажиллагаа бүр ч биш. Бурханы шинэ ажлыг хүлээн авдаггүй хүмүүсийн дэргэд Бурхан байдаггүй, түүнчлэн Бурханы ерөөл, хамгаалалт байдаггүй. Тэдний үг, үйлдлийн ихэнх нь Ариун Сүнсний ажлын урьдын шаардлагатай зууралддаг; тэдгээр нь хоосон сургаал болохоос үнэн биш юм. Энэ хүмүүсийн цугларалт нь шашин төдийхөн юм гэдгийг батлахад эдгээр хоосон сургаал, дүрэм журам хангалттай; тэд бол сонгогдсон хүмүүс ч биш, Бурханы ажлын бай ч биш. Тэд бүгдийн цугларалтыг шашны томоохон цуглаан гэж л нэрлэхээс биш чуулган гэж нэрлэж болохгүй. Энэ бол өөрчлөгдөшгүй баримт юм. Тэдэнд Ариун Сүнсний шинэ ажил байдаггүй; тэдний хийдэг зүйл шашны үнэр ханхлуулж, амьдран харуулдаг зүйл нь шашнаар бялхдаг мэт санагддаг; тэд Ариун Сүнстэй хамт байдаггүй, ажлыг нь эзэмшдэггүй, тэр ч бүү хэл, Ариун Сүнсний сахилгажуулалт, эсвэл гэгээрлийг хүлээн авах эрхгүй. Энэ хүмүүс цөмөөрөө амьгүй цогцос, сүнслэг байдалгүй өтнүүд юм. Тэдэнд хүний тэрслүү байдал, эсэргүүцлийн талаар ямар ч мэдлэг байхгүй, хүний бүх муу үйлийн тухай ямар ч мэдлэг байдаггүй, үүгээр ч үл барам тэд Бурханы ажил, Бурханы одоогийн хүслийг бүгдийг нь мэддэггүй. Тэд бүгдээрээ мэдлэггүй, олиггүй хүмүүс, мөн итгэгчид гэж дуудахад ч зохихгүй өөдгүй амьтад! Тэдний хийдэг юу ч Бурханы удирдлагын ажилтай хамаагүй байдаг ба Бурханы төлөвлөгөөнд хохирол учруулж бүр ч чаддаггүй. Тэдний үг, үйлдэл хэтэрхий жигшүүртэй, хэтэрхий өрөвдөлтэй бөгөөд зүгээр л дурдахын ч хэрэггүй. Ариун Сүнсний урсгалд байдаггүй хүмүүсийн хийсэн зүйлс Ариун Сүнсний шинэ ажилтай ямар ч хамаагүй байдаг. Ийм учраас тэд юу ч хийлээ гэсэн тэдэнд Ариун Сүнсний сахилгажуулалт байдаггүй, түүнчлэн Ариун Сүнсний гэгээрэл байдаггүй. Учир нь тэд цөмөөрөө үнэнийг хайрладаггүй, Ариун Сүнсээр жигшигдэж, гологдсон хүмүүс юм. Тэд махан биеэр алхаж, Бурханы пайзын дор хүссэн бүхнээ үйлддэг учраас тэднийг мууг үйлдэгчид гэдэг. Бурханыг ажиллаж байх үед тэд Түүнд зориуд өсөрхөж, Түүний эсрэг зүгт явдаг. Хүн Бурхантай хамтран ажиллаж чаддаггүй нь өөрөө туйлын тэрслүү хэрэг бөгөөд Бурханыг санаатайгаар эсэргүүцдэг тэр хүмүүс тохирох залхаан цээрлүүлэлтээ хүртэхгүй гэж үү? Энэ хүмүүсийн муу үйлийг дурдангуут зарим хүн тэднийг хараахаар тэсэн яддаг, харин тэгэхэд Бурхан тэднийг үл ойшоодог. Хүний хувьд тэдний үйлдэл Бурханы нэртэй холбоотой харагддаг боловч үнэндээ Бурханы хувьд тэд Түүний нэр болон гэрчлэлтэй ямар ч холбоогүй байдаг. Энэ хүмүүс юу ч хийлээ гэсэн энэ нь Бурхантай хамаагүй: Энэ нь Түүний нэр болон Түүний өнөөдрийн ажлын аль алинтай ямар ч хамаагүй байдаг. Энэ хүмүүс өөрсдийгөө доромжилж, Сатаныг илтгэдэг; тэд бол уур хилэнгийн өдөрт зориулан муу үйлийг хурааж байгаа мууг үйлдэгчид юм. Уур хилэнгийн өдөр хараахан ирээгүй байгаа учраас өнөөдөр тэд юу ч хийлээ гэсэн, Бурханы удирдлагад саад болоогүй, Бурханы шинэ ажилтай ямар ч хамаагүй байгаа тохиолдолд тийм хүмүүс харгалзах залхаан цээрлүүлэлтэд өртөхгүй.

Бурхан аль хэдийн харьцчихсан байх ёстой гэж хүмүүсийн итгэдэг зүйл их байдаг бөгөөд тэрхүү мууг үйлдэгчид аль болох хурдан залхаан цээрлүүлэлтэд өртөх ёстой гэж тэд боддог. Гэхдээ Бурханы удирдлагын ажил хараахан төгсгөлдөө очоогүй, уур хилэнгийн өдөр арай ирээгүй байгаа учраас зөв шударга бус хүмүүс шударга бус үйлээ үргэлжлүүлэн хийсээр байна. Зарим хүн, “Шашны хүмүүс Ариун Сүнстэй хамт байдаггүй, тэдэнд Ариун Сүнсний ажил байдаггүй бөгөөд тэд Бурханы нэрийг шившиглэдэг; тэгвэл Бурхан тэдний цадиггүй зан авирыг хүлцэн тэвчихийн оронд яагаад тэднийг устгадаггүй юм бэ?” гэж хэлдэг. Сатаныг харуулж, махан биеийг илэрхийлдэг энэ хүмүүс бол мэдлэггүй, олиггүй хүмүүс юм; тэд бол гажууд хүмүүс билээ. Тэд Бурхан хүмүүсийн дунд хэрхэн ажилладгийг ойлгож авахаасаа өмнө Бурханы уур хилэн ирэхийг харахгүй бөгөөд бүрэн байлдан дагуулагдмагцаа тэр мууг үйлдэгчид бүгд залхаан цээрлүүлэлтээ хүртэж, нэг нь ч уур хилэнгийн өдрөөс зугтан зайлж чадахгүй. Одоо үе бол хүнийг шийтгэх цаг биш бөгөөд Бурханы удирдлагад хохирол учруулах хүмүүс байхгүй бол байлдан дагуулалтын ажлыг явуулах цаг юм, харин байгаа тохиолдолд тэд хийсэн үйлдлийнхээ ноцтой байдалд үндэслэн шийтгэл хүртэх болно. Хүн төрөлхтнийг удирдах Бурханы удирдлагын явцад Ариун Сүнсний урсгал дотор байгаа бүх хүн Бурхантай холбоотой байдаг. Ариун Сүнсний жигшин, голдог хүмүүс Сатаны нөлөөн дор амьдардаг ба хэрэгжүүлдэг зүйлс нь Бурхантай ямар ч холбоогүй байдаг. Бурханы шинэ ажлыг хүлээн авч, Бурхантай хамтран ажилладаг хүмүүс л Бурхантай холбоотой байдаг, учир нь Бурханы ажил хүн хүлээн авдаг эсэхээс үл хамааран бүх хүнд чиглэдэг биш, харин үүнийг хүлээн авдаг хүмүүс рүү л чиглэдэг. Бурханы хийдэг ажилд үргэлж бай байдаг бөгөөд дур зоргоор хийгддэггүй. Сатантай холбоотой хүмүүс Бурханд гэрчлэл хийхэд тохирдоггүй, Бурхантай хамтран ажиллахад бүр ч тохирдоггүй.

Ариун Сүнсний ажлын үе шат бүр ч бас хүний гэрчлэлийг шаарддаг. Ажлын үе шат бүр Бурхан, Сатан хоёрын хоорондох тулаан бөгөөд тулааны бай нь Сатан байдаг байхад энэхүү ажлаар төгс болгуулах нэгэн нь хүн юм. Бурханы ажил үр өгөөжөө өгөх эсэх нь Бурханыг гэрчлэх хүний гэрчлэлийн байдлаас хамаардаг. Энэ гэрчлэл нь Өөрийг нь дагадаг хүмүүсээс Бурханы шаарддаг зүйл юм; энэ нь Сатаны өмнө хийгддэг гэрчлэл, мөн Түүний ажлын үр дүнгийн нотолгоо билээ. Бурханы удирдлага нь бүхэлдээ гурван үе шатанд хуваагддаг бөгөөд үе шат бүрд хүнд тохирох шаардлага тавигддаг. Түүнчлэн эрин үе өнгөрч, урагшлахын хэрээр бүх хүн төрөлхтөнд тавих Бурханы шаардлага улам өндөр болдог. Тиймээс хүн “Үг нь махбодоор илэрсэн” баримтыг харах хүртэл Бурханы удирдлагын энэ ажил алхам алхмаар оргилдоо хүрч, ийм маягаар хүнд тавих шаардлага улам өндөр болж, хүний гэрчлэл хийх шаардлага ч бас улам өндөрсдөг. Хүн Бурхантай үнэхээр хамтран ажиллах чадвартай байх тусам Бурхан алдар сууг төдий чинээ олж авдаг. Хүний хамтын ажиллагаа бол түүний хийх хэрэгтэй гэрчлэл бөгөөд түүний хийдэг гэрчлэл нь хүний хэрэгжүүлэлт юм. Тиймээс Бурханы ажил эцсийн үр дүнтэй байх

эсэх нь, мөн жинхэнэ гэрчлэлтэй байж чадах эсэх нь хүний хамтын ажиллагаа болон гэрчлэлтэй нягт холбогддог. Ажил дуусах үед, өөрөөр хэлбэл, Бурханы бүх удирдлага төгсгөлдөө очих үед, хүн илүү өндөр гэрчлэл хийх шаардлагатай болно, мөн Бурханы ажил төгсгөлдөө очих үед хүний хэрэгжүүлэлт болон оролт дээд цэгтээ хүрнэ. Өмнө нь хүнээс, хууль болоод тушаалуудыг сахиж, тэвчээртэй, даруухан байхыг шаарддаг байсан. Харин өнөөдөр хүнээс, Бурханы бүх зохицуулалтад дуулгавартай байж, Бурханыг туйлын их хайрлаж, эцэст нь гай зовлонгийн дунд ч гэсэн Бурханыг хайрласаар байхыг шаарддаг. Энэ гурван үе шат нь, бүхий л удирдлагынхаа хугацаанд алхам алхмаар хүнд тавьдаг Бурханы шаардлагууд юм. Бурханы ажлын үе шат бүр сүүлийнхээсээ илүү гүнзгийрдэг ба үе шат бүрд хүнд тавих шаардлага сүүлийнхээсээ илүү гүн гүнзгий болдог, ийм маягаар Бурханы бүхий л удирдлага алгуурхан хэлбэрждэг. Яагаад гэвэл, хүнд тавих шаардлага улам өндөр болох тусам хүний зан чанар Бурханы шаардсан стандартад бүр их дөхдөг, зөвхөн тэр үед л бүх хүн төрөлхтөн Сатаны нөлөөллөөс аажмаар ангижирдаг ба Бурханы ажил бүрэн дуусгавар болоход бүх хүн төрөлхтөн Сатаны нөлөөллөөс аврагдсан байх болно. Тэр цаг ирэхэд Бурханы ажил төгсгөлдөө хүрсэн байх бөгөөд хүн зан чанараа өөрчлөхийн тулд Бурхантай цаашид хамтран ажиллах хэрэггүй болж, бүх хүн төрөлхтөн Бурханы гэрэлд амьдарна, тэр үеэс хойш Бурханыг эсэргүүцэх эсэргүүцэл юм уу тэрслүү байдал гэж байхаа болино. Бурхан ч бас хүнд ямар ч шаардлага тавихгүй, хүн Бурхан хоёрын хооронд илүү эв зохицолтой хамтын ажиллагаа байх болно, энэ нь хүн, Бурхан хоёрын хамтын амьдрал буюу Бурханы удирдлага бүрэн дуусгавар болсны дараа, Бурхан хүнийг Сатаны савраас бүрэн аварсаны дараа бий болсон амьдрал байх болно. Бурханы мөрийг ойрхон дагаж чадахгүй хүмүүс ийм амьдралд хүрч чадахгүй. Тэд бүгд харанхуйд унаж, гашуудан уйлж, шүдээ хавирна; тэд бол Бурханд итгэдэг ч Түүнийг дагадаггүй, Бурханд итгэдэг ч Түүний бүх ажилд дуулгавартай байдаггүй хүмүүс юм. Хүн Бурханд итгэдэг тул Бурханы мөрийг алхам алхмаар ойрхон дагах ёстой; мөн “Хургыг хаашаа ч явсан дагах” ёстой. Зөвхөн энэ хүмүүс л үнэн замыг эрж хайдаг хүмүүс бөгөөд зөвхөн тэд л Ариун Сүнсний ажлыг мэддэг хүмүүс юм. Бичиг үсэг, хоосон номлолыг боол мэт дагадаг хүмүүс бол Ариун Сүнсний ажлаар таягдан хаягдсан хүмүүс билээ. Цаг үе бүрд Бурхан шинэ ажил эхлүүлдэг, цаг үе бүрд хүмүүсийн дунд шинэ эхлэл байх болно. Хэрэв хүн ганцхан эрин үед хэрэглэгддэг “Ехова бол Бурхан”, “Есүс бол Христ” гэсэн үнэнийг л дагадаг бол хэзээ ч Ариун Сүнсний ажлыг дагаж дийлэхгүйгээр барахгүй, үүрд Ариун Сүнсний ажлыг олж авах чадваргүй байх болно. Бурхан хэрхэн ажилладгаас үл хамааран, хүн өчүүхэн ч эргэлзээгүйгээр, ойрхон дагадаг. Ингэвэл Ариун Сүнс яаж хүнийг таягдан хаяж чадах юм бэ? Бурхан юу ч хийдэг бай, хүн энэ нь Ариун Сүнсний ажил гэдэгт итгэлтэй байгаад, Ариун Сүнсний ажилд эргэлзэлгүйгээр хамтран ажиллаж, Бурханы шаардлагад нийцэхээр хичээж байвал яалаа гэж шийтгүүлэх юм бэ? Бурханы ажил хэзээ ч зогсоогүй, Түүний мөр хэзээ ч

зогсоогүй, удирдлагын ажлаа дуусгахаас өмнө Тэр үргэлж завгүй байсан ба хэзээ ч зогсдоггүй. Гэхдээ хүн бол өөр: Ариун Сүнсний ажлын өчүүхэн хэсгийг олж авсныхаа дараа хүн үүнийг хэзээ ч өөрчлөгдөхгүй гэж үздэг; өчүүхэн хэмжээний мэдлэг олж авчихаад Бурханы илүү шинэ ажлын мөрийг дагахаар урагш явдаггүй; Бурханы ажлын өчүүхэн хэсгийг харчихаад Бурханыг ямар нэг модон хүн мэт даруй тодорхойлж, Бурхан үүрд өөрийнх нь хардаг шиг төрхтэй байна, өнгөрсөнд ямар байсан, ирээдүйд ч мөн тийм байх болно гэж итгэдэг; өнгөц төдий мэдлэг олж аваад хүн бардамнан, өөрийгөө мартаж, ердөө оршин байдаггүй Бурханы зан чанар болон оршихуйг дураараа тунхаглаж эхэлдэг; Ариун Сүнсний ажлын нэг үе шатыг мэддэг болчихоод, ямар хүн Бурханы шинэ ажлыг тунхаглаж байгаа нь хамаагүй, хүн үүнийг хүлээн авдаггүй. Эдгээр нь Ариун Сүнсний шинэ ажлыг хүлээн авч чаддаггүй хүмүүс юм; тэд бол шинэ зүйлсийг хүлээн авах чадваргүй хэтэрхий хуучинсаг хүмүүс билээ. Ийм хүмүүс Бурханд итгэдэг ч бас Бурханыг голдог. Израильчууд “Есүст итгэлгүй, зөвхөн Еховад итгэж байсан” нь буруу байсан гэж хүн итгэдэг ч дийлэнх хүмүүс “зөвхөн Еховад итгэж, Есүсийг голох”, “Мессиагийн ирэлтийг хүсэн хүлээдэг ч Есүс хэмээх Мессиаг эсэргүүцэх” дүрд тоглодог. Тэгэхээр хүмүүс Ариун Сүнсний ажлын нэг үе шатыг хүлээн авсныхаа дараа Сатаны ноёрхол дор амьдарсаар байж, Бурханы ерөөлийг мөн л хүлээн авдаггүйд гайхах юмгүй. Энэ нь хүний тэрслүү байдлын үр дүн биш гэж үү? Өнөөдрийн шинэ ажилтай хөл нийлүүлээгүй, дэлхий даяарх Христийн шашны хүмүүс бүгд өөрсдийгөө азтай байх болно гэж найдан, Бурхан хүсэл бүрийг нь биелүүлнэ гэж боддог. Гэсэн атлаа, Бурхан яагаад тэднийг гурав дахь тэнгэр лүү аваачихыг итгэлтэй хэлж чаддаггүй, мөн Есүс хэрхэн цагаан үүл хөлөглөн тэднийг авахаар ирэх талаар ч бат итгэлтэй байж чаддаггүй, түүгээр ч үл барам төсөөлсөн тэр өдөр нь Есүс үнэхээр цагаан үүл хөлөглөн ирэх эсэхийг ч баттай хэлж чаддаггүй. Тэд бүгдээрээ түгшиж, яахаа мэддэггүй; урсгал бүрээс ирсэн, янз бүрийн цөөн тооны хүмүүсийг Бурхан нэг бүрчлэн авах эсэхийг ч мэддэггүй. Бурханы одоо хийдэг ажил, өнөөгийн эрин үе, Бурханы хүсэл—эдгээрийн алийг нь ч тэд ухаардаггүй бөгөөд хуруугаараа хоног тоолохоос өөр юу ч хийж чаддаггүй. Хурганы мөрийг эцсээ хүртэл дагадаг хүмүүс л эцсийн ерөөлийг хүртэж чадна, харин эцсээ хүртэл дагах чадваргүй атлаа бүхнийг олж авсан гэж боддог тэр “ухаалаг хүмүүс” Бурханы илрэлтийг харж чадахгүй. Тэд бүгд өөрсдийгөө газар дэлхий дээрх хамгийн ухаантай хүн гэж үздэг, Бурханы ажлын үргэлжилсэн хөгжлийг ямар ч шалтгаангүй тасалдаг бөгөөд Бурханд “чин үнэнч байж, Бурханыг дагаж, Бурханы үгийг сахидаг” болохоор Бурхан өөрсдийг нь тэнгэр лүү авч явна гэдэгт асар их итгэдэг юм шиг санагддаг. Тэд Бурханы хэлсэн үгэнд “чин үнэнч” ханддаг ч Ариун Сүнсний ажлыг эсэргүүцэж, заль мэх, ёрын мууг үйлддэг учраас үг, үйлдэл нь маш жигшүүртэй байдаг. Эцсийг нь хүртэл дагадаггүй, Ариун Сүнсний ажилтай эн зэрэгцэж чаддаггүй, зөвхөн хуучин ажилтай зууралддаг хүмүүс Бурханд үнэнч байж чадахаагүйгээр үл барам, харин ч эсрэгээрээ Бурханыг эсэргүүцдэг хүмүүс болж,

шинэ эринд гологдон, шийтгэгдэх хүмүүс болсон. Тэднээс илүү өрөвдөлтэй хүмүүс гэж байх уу? Хуучин хуулийг голж, шинэ ажлыг хүлээн авдаг бүх хүн мөс чанаргүй гэж олонх нь итгэдэг. Зөвхөн “мөс чанарын” талаар ярьдаг, Ариун Сүнсний ажлыг мэддэггүй энэ хүмүүсийн хувьд, эцэстээ мөс чанар нь өөрсдийнх нь хэтийн ирээдүйг сүйрүүлэх болно. Бурханы ажил дүрэм журам мөрддөггүй, Өөрийнх нь ажил байлаа ч гэсэн Бурхан мөн л үүнтэй зууралддаггүй. Үгүйсгэх ёстой зүйлийг үгүйсгэж, таягдан хаях ёстой зүйлийг таягдан хаях ёстой. Гэсэн ч хүн Бурханы удирдлагын ажлын өчүүхэн хэсгээс зуурч, өөрийгөө Бурхантай дайсагнасан байр сууринд тавьдаг. Энэ нь хүний утгагүй байдал биш гэж үү? Хүний мэдлэггүй байдал биш гэж үү? Бурханы ерөөлийг олж авахгүй байх вий гэж эмээж, болгоомжлох тусам хүмүүс илүү их ерөөл олж авч чадахгүй бөгөөд эцсийн ерөөлийг хүртэж бүр чадахгүй. Хуулийг боол мэт сахидаг хүмүүс бүгд хуулинд туйлын үнэнч болохоо харуулдаг ба хуулинд үнэнч байдлаа харуулах тусмаа төдий чинээ Бурханыг эсэргүүцдэг босогчид болдог. Учир нь одоо үе бол Хуулийн эрин үе биш, харин Хаанчлалын эрин үе бөгөөд өнөөдрийн ажлыг урьдын ажилтай жишиж болохгүй, өнгөрсөн үеийн ажлыг өнөөдрийн ажилтай харьцуулж ч болохгүй. Бурханы ажил өөрчлөгдсөн, хүний хэрэгжүүлэлт ч бас өөрчлөгдсөн; энэ нь хуулиас зуурч, загалмай үүрэх явдал биш, тиймээс хууль болон загалмайд хандах хүмүүсийн үнэнч байдал Бурханы сайшаалыг хүртэхгүй.

Хүн Хаанчлалын эрин үед бүрмөсөн бүрэн төгс болгуулна. Байлдан дагуулалтын ажлын дараа хүн цэвэршүүлэлт, гай зовлон амсах болно. Энэ гай зовлонгийн үеэр ялан гарч, гэрчлэлд зогсож чадах хүмүүс бол эцэстээ бүрэн төгс болгуулах хүмүүс юм; тэд бол ялагчид билээ. Энэ гай зовлонгийн үеэр хүн энэ цэвэршүүлэлтийг хүлээн авах шаардлагатай бөгөөд энэ цэвэршүүлэлт нь Бурханы ажлын сүүлийн тохиолдол юм. Бурханы бүх удирдлагын ажил дуусгавар болохын өмнө хүн сүүлийн удаа цэвэршүүлэгдэж, Бурханыг дагадаг бүх хүн энэхүү сүүлчийн туршилтыг, энэ сүүлчийн цэвэршүүлэлтийг хүлээн авах ёстой. Гай зовлонд автсан хүмүүс Ариун Сүнсний ажилгүй, Бурханы удирдамжгүй байдаг боловч үнэхээр байлдан дагуулагдсан, Бурханыг үнэхээр эрж хайдаг хүмүүс эцэстээ бат зогсоно; тэд бол хүн чанартай, Бурханыг үнэхээр хайрладаг хүмүүс юм. Бурхан юу ч хийдэг бай, энэ ялагчид үзэгдлээс салахгүй бөгөөд гэрчлэлдээ бүтэлгүйтэлгүйгээр үнэнийг хэрэгжүүлсээр байх болно. Тэд бол эцэстээ үлэмж гай зовлонгоос гарч ирэх хүмүүс юм. Үймээн самууныг өөрсдийнхөө төлөө ашигладаг хүмүүс өнөөдөр бусдын хүчээр хоолоо олж идсээр байх ч эцсийн гай зовлон, эцсийн туршилтаас нэг нь ч зугтаж чадахгүй. Ялах хүмүүсийн хувьд тийм гай зовлон нь үлэмж их цэвэршүүлэлт юм; харин үймээн самууныг өөрсдийнхөө төлөө ашигладаг хүмүүсийн хувьд энэ нь бүрмөсөн таягдан хаях ажил мөн. Тэднийг яаж ч шалгасан бай, зүрх сэтгэлд нь Бурхан байдаг хүмүүсийн үнэнч байдал өөрчлөгдөхгүй хэвээр үлддэг; харин зүрх сэтгэлд нь Бурхан байдаггүй хүмүүсийн хувьд, Бурханы ажил махан биед нь ашиггүй болмогц тэд Бурханыг үзэх үзэл бодлоо өөрчилж, бүр Бурханаас салж

оддог. Ийм хүмүүс бол эцэстээ бат зогсохгүй, Бурханы ерөөлийг л хайдаг, өөрсдийгөө Бурханы төлөө зарцуулж, зориулах хүсэлгүй хүмүүс юм. Ийм олиггүй хүмүүс Бурханы ажил дуусгавар болох үед бүгд хөөгдөх ба огт өрөвдүүлэх үнэ цэнгүй. Хүн чанаргүй хүмүүс Бурханыг үнэхээр хайрлах чадваргүй. Орчин нөхцөл нь амар тайван, аюулгүй, эсвэл ашигтай байгаа үед тэд Бурханд бүрэн дуулгавартай байдаг боловч хүссэн зүйлээ алдвал, эсвэл эцэстээ няцаагдвал даруй эсэргүүцдэг. Ердөө ганцхан шөнийн дотор тэд инээмсэглэсэн, “сайхан сэтгэлтэй” хүн байснаа муухай царайтай, хэрцгий алуурчин болж, өчигдрийн өглөгийн эзэнтэйгээ ямар ч шалтаг, шалтгаангүйгээр гэнэт заналт дайсан мэт харьцдаг. Нүд цавчилгүй хөнөөж мэдэх энэ чөтгөрүүдийг хэрвээ хөөхгүй бол тэд далд аюул болохгүй гэж үү? Хүнийг аврах ажил нь байлдан дагуулалтын ажил дууссаны дараа биелдэггүй. Байлдан дагуулалтын ажил дууссан хэдий ч хүнийг ариусгах ажил дуусаагүй; хүн бүрэн ариусгагдаж, Бурханд үнэхээр захирагддаг хүмүүс бүрэн төгс болгуулж, зүрх сэтгэлдээ Бурхангүй дүр эсгэгчид зайлуулмагц л ийм ажил дуусна. Бурханы ажлын сүүлийн үе шатанд Түүнийг сэтгэл хангалуун болгодоггүй хүмүүс бүрмөсөн таягдан хаягдах ба таягдан хаягддаг хүмүүс нь диаволынх юм. Тэд Бурханы сэтгэлийг хангалуун байлгах чадваргүй тул Бурханы эсрэг тэрсэлдэг бөгөөд хэдий энэ хүмүүс өнөөдөр Бурханыг дагадаг ч эцэстээ үлдэх хүмүүс мөн гэдгийг энэ нь баталдаггүй. “Бурханыг эцсээ хүртэл дагадаг хүмүүс аврал хүртэнэ” гэдэг үгэнд байгаа “дагах” гэдгийн утга учир нь гай зовлонгийн дунд бат зогсох гэсэн үг юм. Өнөөдөр, Бурханыг дагах нь амархан гэж олон хүн итгэдэг, гэхдээ Бурханы ажил дуусах гэж байх үед чи “дагах” гэдгийн жинхэнэ утгыг мэдэх болно. Өнөөдөр чи байлдан дагуулагдсаныхаа дараа Бурханыг дагах чадвартай байлаа ч төгс болгуулах хүмүүсийн нэг мөн гэдгийг чинь энэ нь баталдаггүй. Шалгалт туулах чадваргүй, гай зовлонгийн дунд ялгуусан байх чадваргүй хүмүүс эцэстээ бат зогсож чадахгүй тул Бурханыг эцсээ хүртэл дагаж чадахгүй. Бурханыг үнэхээр дагадаг хүмүүс ажлынхаа туршилтыг давж гарах чадвартай байдаг байхад Бурханыг үнэхээр дагадаггүй хүмүүс Бурханы ямар ч шалгалтыг тэсэн гарах чадваргүй байдаг. Эрт орой хэзээ нэгэн цагт тэд хөөгдөнө, харин ялагчид хаанчлалд үлдэнэ. Хүн Бурханыг үнэхээр эрж хайдаг эсэх нь түүний ажлын туршилтаар, өөрөөр хэлбэл, Бурханы шалгалтаар тодорхойлогддог бөгөөд хүний өөрийн шийдвэртэй ямар ч хамаагүй. Бурхан аливаа хүнийг дур зоргоороо голдоггүй; Түүний хийдэг бүхэн хүнийг бүрэн үнэмшүүлж чадна. Тэрээр хүнд үл үзэгдэх юмс, эсвэл хүн үнэмшихээргүй ажил хийдэггүй. Хүний итгэл үнэн худал эсэх нь баримтаар нотлогддог ба хүн үүнийг шийдэж чадахгүй. “Буудай үрийн сүүл болж чадахгүй, үрийн сүүл буудай болж чадахгүй” гэдэг нь эргэлзээгүй. Бурханыг үнэхээр хайрладаг бүх хүн эцэстээ хаанчлалд үлдэх ба Бурхан Өөрийг нь үнэхээр хайрладаг хэнд ч зохисгүй хандахгүй. Хаанчлал дахь ялагчид өөр өөр чиг үүрэг болон гэрчлэлдээ үндэслэн тахилч юм уу дагагч болж үйлчлэх бөгөөд гай зовлон дунд ялгуусан байдаг бүх хүн хаанчлал доторх тахилчдын бүлэг болно. Орчлон ертөнц даяарх сайн мэдээний ажил дуусгавар болох үед тахилчдын бүлэг байгуулагдана.

Тэр цаг ирэхэд хүн Бурханы хаанчлалд үүргээ гүйцэтгэж, хаанчлал дотор Бурхантай хамт амьдрах ёстой. Тахилчдын бүлэгт ахлах тахилчид болон тахилчид байх ба үлдсэн хэсэг нь Бурханы хөвгүүд, ардууд байх болно. Энэ бүхэн нь гай зовлонгийн үеэр Бурханд хийсэн гэрчлэлээр нь тодорхойлогддог; тэдгээр нь дур зоргоороо өгдөг цол биш. Хүн байр сууриа олмогц Бурханы ажил зогсоно, учир нь бүгд төрлөөрөө ангилагдаж, анхдагч байр сууриндаа эргэн очдог бөгөөд энэ нь Бурханы ажил гүйцэлдсэний тэмдэг, Бурханы ажил болон хүний хэрэгжүүлэлтийн эцсийн үр дүн, мөн Бурханы ажлын үзэгдэл болон хүний хамтын ажиллагааны биелэлт юм. Эцэст нь хүн Бурханы хаанчлалд амарч, Бурхан ч гэсэн оршин суудаг газартаа амрахаар буцна. Энэ нь Бурхан, хүн хоёрын 6,000 жилийн хамтын ажиллагааны эцсийн үр дүн байх болно.

ХРИСТИЙН МӨН ЧАНАР БОЛ ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГИЙН ХҮСЭЛД ДУУЛГАВАРТАЙ БАЙХ ЯВДАЛ ЮМ

Бие махбодтой болсон Бурханыг Христ гэдэг ба Христ бол Бурханы Сүнсний өмссөн махбод билээ. Энэхүү махбод нь махан биетэй ямар ч хүнтэй адилгүй. Христ бол мах, цуснаас бүрдсэн бус, харин Сүнсний биелэл учраас ийм ялгаа байгаа юм. Түүнд хэвийн хүн чанар, бүрэн дүүрэн бурханлаг чанарын аль аль нь бий. Түүний бурханлаг чанарыг ямар ч хүн эзэмшдэггүй. Түүний хэвийн хүн чанар нь махбод дахь бүх хэвийн үйл ажиллагааг хангадаг байхад бурханлаг чанар нь Бурханы Өөрийн ажлыг гүйцэтгэдэг. Түүний хүн чанар ч бай, бурханлаг чанар ч бай, аль аль нь тэнгэрлэг Эцэгийн хүсэлд захирагддаг. Христийн мөн чанар бол Сүнс буюу бурханлаг чанар юм. Тиймээс, Түүний мөн чанар нь Бурханы Өөрийн мөн чанар байдаг; энэхүү мөн чанар Өөрийнх нь ажилд саад болохгүй, Тэрээр Өөрийнхөө ажлыг сүйтгэх ямар нэг зүйлийг хийж яавч чадахгүй, Өөрийнх нь хүсэлд харшилдаг үгийг хэзээ ч хэлдэггүй. Тиймээс, бие махбодтой болсон Бурхан нь Өөрийнхөө удирдлагад саад болох ямар нэг ажлыг бүр хэзээ ч хийхгүй. Үүнийг бүх хүн ойлгох ёстой. Ариун Сүнсний ажлын мөн чанар нь хүнийг аврахын төлөө, Бурханы Өөрийн удирдлагын төлөө байдаг. Үүний адилаар, Христийн ажил ч бас хүнийг аврахын төлөө, Бурханы хүслийн төлөө байдаг. Бурхан махбод болсон болохоор мөн чанар нь Түүний махбод дотор биеллээ олж, улмаар Түүний махбод ажлыг нь хариуцахад хангалттай болдог. Тиймээс, бие махбодтой болсон байх хугацаанд Бурханы Сүнсний бүх ажил нь Христийн ажлаар солигддог бөгөөд бие махбодтой болсон хугацааны туршид бүх ажлын цөм нь Христийн ажил байдаг. Үүнийг өөр ямар ч эрин үеийн ажилтай хольж болохгүй. Бурхан махбод болсон тул махбодынхоо ялгамж чанараар ажилладаг; Тэр махбодоор ирдэг тул хийх учиртай ажлаа махбодоор хийж дуусгадаг. Бурханы Сүнс ч бай, Христ ч бай, хоёулаа

Бурхан Өөрөө бөгөөд хийх учиртай ажлаа хийж, биелүүлэх учиртай үйлчлэлээ биелүүлдэг.

Бурханы мөн чанар нь өөрөө эрх мэдэл эзэмшдэг боловч Өөрөөс нь гардаг эрх мэдэлд Тэр бүрэн захирагдаж чаддаг. Сүнсний ажил ч бай, махбодын ажил ч бай, аль нь ч нөгөөтэйгөө зөрчилддөггүй. Бурханы Сүнс бол бүх бүтээлийн дээрх эрх мэдэл юм. Бурханы мөн чанартай махбод ч бас эрх мэдэл эзэмшдэг, гэхдээ махбод дахь Бурхан нь тэнгэрлэг Эцэгийн хүслийг дуулгавартай дагадаг бүх ажлыг хийж чаддаг. Үүнд нэг ч хүн хүрч, ухан ойлгож чадахгүй. Бурхан Өөрөө эрх мэдэл боловч Түүний махбод эрх мэдэлд нь захирагдаж чадна. “Эцэг Бурханы хүслийг Христ дуулгавартай дагадаг” гэдэг үгийн цаад учир энэ билээ. Бурхан бол Сүнс бөгөөд авралын ажлыг хийж чаддаг, хүн болох үедээ ч үүнийг хийж чаддаг. Ямартай ч, Бурхан Өөрөө Өөрийнхөө ажлыг хийдэг; Тэр саад ч болдоггүй, хөндлөнгөөс ч оролцдоггүй, өөр хоорондоо зөрчилддөг ажил бүр ч хийдэггүй, учир нь Сүнс, махбод хоёрын хийдэг ажлын мөн чанар адилхан юм. Сүнс ч бай, махбод ч бай, хоёулаа нэг хүслийг биелүүлэхийн төлөө ажиллаж, адилхан ажлыг удирддаг. Сүнс, махбод хоёр харьцуулшгүй хоёр өөр чанартай хэдий ч мөн чанар нь адилхан; хоёулаа Бурханы Өөрийн мөн чанар болон ялгамж чанарыг агуулдаг. Бурханд Өөрт нь дуулгаваргүй байдлын ямар ч элемент байхгүй; Түүний мөн чанар нь сайн. Тэр бол бүх гоо үзэсгэлэн, сайн сайхан, бүх хайрын илэрхийлэл билээ. Бурхан махбодод байхдаа ч гэсэн, Эцэг Бурханд дуулгаваргүй хандах юу ч хийдэггүй. Амиа золиослоод ч хамаагүй, Тэр чин сэтгэлээсээ тийнхүү үйлдэхэд бэлэн байх ба өөр ямар ч сонголт хийхгүй. Бурханд Өөрийгөө зөвтгөж, чухалчилдаг, ихэрхүү, биеэ тоосон байдлын ямар ч элемент байдаггүй; шударга бус зангийн ямар ч элемент байдаггүй. Бурханд дуулгаваргүй байдаг бүхэн Сатанаас гардаг; Сатан бол бүх муу муухай, хорон муугийн эх сурвалж билээ. Хүнийг Сатан завхруулж, боловсруулсан учраас л Сатаныхтай адил чанартай байдаг. Христийг Сатан завхруулаагүй, иймээс Тэр зөвхөн Бурханы шинж чанарыг агуулдаг ба Сатаны шинж чанарын аль нь ч байдаггүй. Ажил хэчнээн хэцүү бэрх ч бай, махбод хэчнээн сул дорой ч бай хамаагүй, Бурхан махбодод амьдрах зуураа Бурханы Өөрийн ажилд саад болох зүйл хэзээ ч хийхгүй, Эцэг Бурханы хүслийг дуулгаваргүй байдлаар бүр ч хаяхгүй. Тэрээр Эцэг Бурханы хүслийг эсэргүүцсэний оронд бие махбодын зовлон туулахыг илүүд үзнэ; Есүс “Эцэг минь, хэрвээ боломжтой бол энэ аягыг Надаас өнгөрүүлээч; гэхдээ Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” гэж залбиран хэлсэнтэй энэ нь яг адилхан юм. Хүмүүс өөрийнхөө сонголтыг хийдэг, харин Христ тэгдэггүй. Хэдий Тэр Бурханы Өөрийн ялгамж чанартай ч махбодын өнцгөөс Эцэг Бурханы хүслийг мөн л эрж хайдаг ба Өөрт нь Эцэг Бурханы даалгасан зүйлийг биелүүлдэг. Энэ нь хүний хүрч чадахгүй зүйл юм. Сатанаас гардаг зүйл Бурханы мөн чанартай байж чаддаггүй; харин Бурханд дуулгаваргүй байж, эсэргүүцдэг мөн чанартай байж л чадна. Сатан Бурханд бүрэн дуулгавартай байж чаддаггүй, Бурханы хүслийг дуртайяа дуулгавартай дагаж бүр ч чаддаггүй. Христээс бусад бүх хүн Бурханыг

эсэргүүцэх зүйл хийж магадгүй бөгөөд Бурханы даалгасан ажлыг нэг ч хүн шууд өөртөө авч чадахгүй; нэг ч хүн Бурханы удирдлагыг өөрсдийн гүйцэтгэх үүрэг гэж үзэж чаддаггүй. Христийн мөн чанар нь Эцэг Бурханы хүсэлд захирагдах явдал юм; Бурханы эсрэг дуулгаваргүй байдал бол Сатаны шинж чанар мөн. Энэ хоёр чанар нь нийцдэггүй ба Сатаны шинж чанартай хэнийг ч Христ гэж нэрлэж болохгүй. Хүн Бурханы ажлыг оронд нь хийж чаддаггүйн шалтгаан гэвэл хүнд Бурханы ямар ч мөн чанар байдаггүй. Хүн хувийн ашиг сонирхол, хэтийн ирээдүйнхээ тусын тулд Бурханы төлөө ажилладаг, харин Христ бол Эцэг Бурханы хүслийг биелүүлэхийн тулд ажилладаг.

Христийн хүн чанарыг бурханлаг чанар нь удирддаг. Хэдий Тэр махбодтой ч, хүн чанар нь тэр чигтээ махан биетэй хүнийхтэй адилгүй. Түүнд Өөрийн гэсэн цор ганц зан араншин байдаг бөгөөд үүнийг ч гэсэн бурханлаг чанар нь удирддаг. Түүний бурханлаг чанарт ямар ч сул тал байхгүй; Христийн сул тал гэж хүн чанарынх нь сул талыг хэлдэг. Энэ сул тал нь Түүний бурханлаг чанарыг тодорхой хэмжээнд хязгаарладаг боловч ийм хязгаарлалт нь хэмжээ хязгааргүй бус, харин тодорхой цар хүрээ, цаг хугацаан дотор байдаг. Бурханлаг чанарынхаа ажлыг хэрэгжүүлэх цаг нь болоход, Түүний хүн чанараас үл хамааран энэ нь хийгддэг. Христийн хүн чанарыг бурханлаг чанар нь бүрэн чиглүүлдэг. Түүний хүн чанарын хэвийн амьдралаас гадна хүн чанарынх нь бусад бүх үйлдэлд бурханлаг чанар нь нөлөө үзүүлж, нөлөөлж, удирдаж байдаг. Христ хүн чанартай хэдий ч бурханлаг чанарынх нь ажлыг энэ нь тасалдуулдаггүй бөгөөд яг нарийндаа энэ нь Христийн хүн чанарыг бурханлаг чанар нь чиглүүлдгээс үүдэлтэй; Түүний хүн чанар нь бусадтай харилцахдаа биеэ хэрхэн авч явах тухайд төлөвшөөгүй байдаг ч бурханлаг чанарынх нь хэвийн ажилд нөлөөлдөггүй. Христийн хүн чанар завхраагүй гэж хэлэхдээ Би, Түүний хүн чанарыг бурханлаг чанар нь шууд захирч чаддаг, мөн Тэрээр жирийн хүнийг бодвол илүү эрүүл ухаантай байдаг гэх утгаар хэлдэг юм. Ажилдаа бурханлаг чанараар удирдуулахад Түүний хүн чанар хамгийн тохиромжтой байдаг; Түүний хүн чанар нь бурханлаг чанарын ажлыг хамгийн сайн илэрхийлж чаддаг, мөн ийм ажилд хамгийн сайн захирагдаж чаддаг. Бурхан махбодод ажиллахдаа махан биетэй хүний биелүүлэх учиртай үүргээс хэзээ ч хараа салгадаггүй; Тэрээр тэнгэр дэх Бурханыг чин зүрх сэтгэлээр шүтэн мөргөх чадвартай. Түүнд Бурханы мөн чанар байдаг бөгөөд Түүний ялгамж чанар бол Бурханы Өөрийн ялгамж чанар юм. Тэр гагцхүү газар дээр ирээд, бүтээгдсэн зүйлийн гадаад бүрхүүлтэй бүтээгдсэн зүйл болж, урьд нь Түүнд байгаагүй хүн чанарыг эзэмшсэн. Тэрээр тэнгэр дэх Бурханыг шүтэн мөргөж чаддаг, энэ нь Бурханы Өөрийн оршихуй бөгөөд хүн дуурайшгүй билээ. Түүний ялгамж чанар бол Бурхан Өөрөө. Махбодын өнцгөөс л Тэрээр Бурханыг шүтэн мөргөдөг; тиймээс, “Христ тэнгэр дэх Бурханыг шүтэн мөргөдөг” гэх үг буруу биш. Тэрээр хүнээс яг Өөрийн оршихуйг л шаарддаг; хүнээс ийм зүйл шаардахынхаа өмнө Өөрөө энэ бүхэндээ аль хэдийн хүрсэн байдаг. Тэр Өөрөө ангид байх зуураа бусдад хэзээ ч

шаардлага тавихгүй, учир нь энэ бүхэн Түүний оршихуйг бүрдүүлдэг. Тэр ажлаа хэрхэн хэрэгжүүлдэг нь хамаагүй, Бурханд дуулгаваргүй ханддаг байдлаар авирлахгүй. Тэр хүнээс юу ч шаарддаг байлаа гэсэн, ямар ч шаардлага нь хүний хүрч чадах зүйлээс хэтэрдэггүй. Түүний хийдэг бүхэн Бурханы хүслийг биелүүлдэг бөгөөд Түүний удирдлагын төлөө байдаг. Христийн бурханлаг чанар бүх хүнээс дээр байдаг; тиймээс Тэр бол бүтээгдсэн бүх зүйлээс хамгийн өндөр дээд эрх мэдэл юм. Энэ эрх мэдэл нь Түүний бурханлаг чанар, өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн зан чанар, оршихуй бөгөөд энэ нь Түүний ялгамж чанарыг тодорхойлдог. Тиймээс, Түүний хүн чанар хэчнээн хэвийн ч бай, Түүнд Бурханы Өөрийн ялгамж чанар байдаг гэдэг нь маргаангүй; Тэр ямар өнцгөөс ярьж, Бурханы хүслийг яаж ч дуулгавартай дагадаг байлаа гэсэн, Түүнийг Бурхан Өөрөө биш гэж хэлж болохгүй. Мунхаг, мэдлэггүй хүмүүс Христийн хэвийн хүн чанарыг өө сэв гэж үздэг. Тэр бурханлаг чанарын оршихуйгаа яаж ч илэрхийлж, илчиллээ гэсэн, хүн Түүнийг Христ гэж хүлээн зөвшөөрөх чадваргүй. Христ Өөрийн дуулгавартай, даруу байдлыг харуулах тусам, тэнэг хүмүүс Христийг улам хөнгөн хуумгай авч үздэг. Түүнд гадуурхаж, басамжилсан хандлагаар ханддаг атлаа ихэмсэг дүртэй “агуу хүмүүс”-ийг шүтэхээр ширээн дээр залдаг хүмүүс ч байдаг. Бурханд хандах хүний эсэргүүцэл, дуулгаваргүй байдал нь, бие махбодтой болсон Бурханы мөн чанар Бурханы хүсэлд захирагддаг баримтаас, мөн Христийн хэвийн хүн чанараас үүдэн гардаг; энэ нь Бурханд хандах хүний эсэргүүцэл, дуулгаваргүй байдлын эх үүсвэр юм. Христэд хүн чанарынх нь гадаад төрх байгаагүй, бүтээгдсэн зүйлийн өнцгөөс Эцэг Бурханы хүслийг ч эрж хайгаагүй, харин оронд нь супер хүн чанарыг эзэмшсэн байсан бол хүмүүсийн дунд ямар ч хүн дуулгаваргүй хандахгүй байсан байх. Хүн тэнгэр дэх үл үзэгдэх Бурханд итгэхэд үргэлж бэлэн байдгийн шалтгаан нь тэнгэр дэх Бурханд хүн чанар байдаггүй, бүтээгдсэн зүйлийн ганц ч чанар байдаггүй. Тиймээс хүн үргэлж тэнгэр дэх Бурханд хамгийн их хүндэтгэлтэйгээр ханддаг боловч Христэд басамжилсан хандлага гаргадаг.

Газар дээрх Христ нь Бурханы Өөрийн өмнөөс ажиллах чадвартай хэдий ч махбод дахь дүрээ бүх хүнд харуулах санаа зорилготойгоор ирдэггүй. Тэрээр бүх хүнд Өөрийгөө харуулахаар ирдэггүй; Өөрийнх нь гараар удирдуулах боломжийг хүмүүст олгож, улмаар шинэ эрин үе рүү оруулах гэж Тэр ирдэг. Христийн махбодын чиг үүрэг нь Бурханы Өөрийн ажлын төлөө, өөрөөр хэлбэл, махбод дахь Бурханы ажлын төлөө байдаг болохоос махбодынхаа мөн чанарыг хүмүүст бүрэн ойлгуулахын төлөө байдаггүй. Тэр яаж ч ажиллалаа гэсэн, Түүний хийдэг юу ч махбодын хийж чадах зүйлээс хэтэрдэггүй. Тэр яаж ч ажиллалаа гэсэн, хэвийн хүн чанартай махбодоор ажилладаг бөгөөд Бурханы жинхэнэ төрх байдлыг хүнд бүрэн илчилдэггүй. Үүнээс гадна, махбод дахь Түүний ажил хэзээ ч хүний төсөөлдөг шиг ер бусын, үнэлж баршгүй байдаггүй. Христ махбод дахь Бурханыг Өөрийг нь төлөөлж, Бурханы Өөрийн хийх учиртай ажлыг биечлэн хэрэгжүүлдэг хэдий ч тэнгэр дэх Бурханы оршин тогтнолыг үгүйсгэдэггүй, Өөрийнхөө үйл хэргийг ч

улайран тунхагладаггүй. Харин ч Тэрээр махбод дотроо даруухнаар нуугдсан хэвээр үлддэг. Христээс гадна, өөрсдийгөө Христ хэмээн хуурамчаар зарладаг хүмүүст Түүний чанарууд байдаггүй. Тэрхүү хуурамч Христүүдийн биеэ тоож, өөрсдийгөө өргөмжилдөг зан чанартай харьцуулж үзэх үед, ямархуу махбод үнэхээр Христ вэ гэдэг нь илэрхий болдог. Тийм хуурамч Христүүд хэдий чинээ хуурамч байна, төдий чинээ бардамнадаг бөгөөд хүнийг мэхлэхийн тулд төдий чинээ тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвартай байдаг. Хуурамч Христүүдэд Бурханы чанар байдаггүй; хуурамч Христэд хамаардаг ямар ч элемент Христэд холилдоогүй байдаг. Бурхан махбодын ажлыг гүйцэтгэхийн тулд л махбод болдог болохоос, зүгээр л Өөрийгөө хүмүүст харуулах гэсэндээ тэгдэггүй. Харин ч Тэр Өөрийнхөө ажлаар ялгамж чанараа бататгаж, Өөрийнхөө илчилдэг зүйлээр мөн чанараа баталгаажуулдаг. Түүний мөн чанар үндэслэлгүй биш; ялгамж чанараа Тэр Өөрийн гараар булаан аваагүй; энэ нь Түүний ажил болон мөн чанараар тодорхойлогддог. Хэдий Тэр Бурханы Өөрийн мөн чанартай, Бурханы Өөрийн ажлыг хийх чадвартай ч эцсийн эцэст бас л Сүнстэй адилгүй махбод билээ. Тэр бол Сүнсний чанартай Бурхан биш; харин махбодын бүрхүүлтэй Бурхан юм. Тиймээс, Тэр хэчнээн хэвийн, хэчнээн сул дорой ч байсан бай, мөн Эцэг Бурханы хүслийг яаж ч эрж хайдаг бай хамаагүй, Түүний бурханлаг чанарыг үгүйсгэх аргагүй. Бие махбодтой болсон Бурханд хэвийн хүн чанар болон хэвийн хүн чанарын сул талууд оршдог төдийгүй, бурханлаг чанарынх нь гайхалтай, тайлагдашгүй байдал, түүнчлэн махбод дахь бүх үйл хэрэг нь ч бас оршдог. Тиймээс, Христийн дотор хүн чанар, бурханлаг чанарын аль аль нь үнэхээр, бодитоор оршдог. Энэ нь огтхон ч хоосон, ер бусын зүйл биш. Тэрээр ажил гүйцэтгэх үндсэн зорилготойгоор газар дээр ирдэг; газар дээр ажил гүйцэтгэхийн тулд хэвийн хүн чанартай байх шаардлагатай; эс бөгөөс, Түүний бурханлаг чанарын хүч чадал хэчнээн их байсан ч, анхдагч чиг үүргээ сайтар биелүүлж чадахгүй. Түүний хүн чанар асар их ач холбогдолтой хэдий ч энэ нь Түүний мөн чанар биш. Түүний мөн чанар бол бурханлаг чанар юм; тиймээс газар дээрх үйлчлэлээ хэрэгжүүлж эхлэх мөчид Тэрээр бурханлаг чанарынхаа оршихуйг илэрхийлж эхэлдэг. Түүний хүн чанар нь гагцхүү махбодынхоо хэвийн амьдралыг хангахын төлөө оршдог, ингэснээр Түүний бурханлаг чанар махбодод хэвийн ажиллаж чаддаг; бурханлаг чанар л Түүний ажлыг бүхэлд нь чиглүүлдэг. Өөрийн ажлыг дуусгах үедээ Тэр үйлчлэлээ хэрэгжүүлсэн байх болно. Хүний мэдэх учиртай зүйл бол Түүний бүхий л ажил бөгөөд Өөрийн ажлаар л дамжуулан Тэр Өөрийг нь мэдэх боломжийг хүнд олгодог. Тэрээр ажлынхаа явцад бурханлаг чанарынхаа оршихуйг нэлээд бүрэн илэрхийлдэг бөгөөд энэ нь хүн чанар холилдсон зан чанар юм уу хүний бодол, зан авир холилдсон оршихуй биш. Бүх үйлчлэл нь дуусах цаг ирэхэд Тэр илэрхийлэх учиртай зан чанараа аль хэдийн бүрэн, төгс илэрхийлсэн байх болно. Түүний ажил ямар нэг хүний зааврaар явагддаггүй; Түүний зан чанарын илэрхийлэл ч бас нэлээд чөлөөтэй байдаг бөгөөд оюун санаагаар хянуулж, эсвэл бодлоор боловсруулагддаггүй, харин аяндаа илчлэгддэг. Энэ нь

хэний ч хийж чадахгүй зүйл юм. Хүрээлэн буй орчин хахир хатуу, тааламжгүй байсан ч гэсэн, Тэрээр тохиромжтой цагт нь зан чанараа илэрхийлж чаддаг. Христ болох Нэгэн нь Христийн оршихуйг илэрхийлдэг бол Христ биш хүмүүст Христийн зан чанар байдаггүй. Тиймээс, Түүнийг бүгд эсэргүүцэж, Түүний талаар үзэлтэй боллоо ч гэсэн, Христийн илэрхийлсэн зан чанар Бурханых мөн гэдгийг хүний үзэлд үндэслээд хэн ч үгүйсгэж чадахгүй. Чин зүрх сэтгэлээр Христийг эрэлхийлдэг, эсвэл Бурханыг зориуд эрж хайдаг бүх хүн, Түүний бурханлаг чанарын илэрхийлэлд үндэслээд Христ мөн гэдгийг нь хүлээн зөвшөөрнө. Хүний үзэлтэй нийцдэггүй ямар нэг талаас нь болж Христийг тэд хэзээ ч үгүйсгэхгүй. Хүн хэдий маш мунхаг боловч хүний хүсэл юу болох, Бурханаас юу үүддэг болохыг бүгд яг таг мэдэж байдаг. Гагцхүү өөрсдийнхөө санаа зорилгоос үүдэн олон хүн Христийг санаатайгаар эсэргүүцдэг. Хэрвээ ийм биш байсан бол, Христийн оршин тогтнолыг үгүйсгэх шалтгаан ганц ч хүнд байхгүй байх байв, учир нь Христийн илэрхийлдэг бурханлаг чанар үнэхээр оршин байдаг ба Түүний ажлыг энгийн нүдээр харж болно.

Христийн ажил болон илэрхийлэл мөн чанарыг нь тодорхойлдог. Тэрээр Өөрт нь даалгасан зүйлийг чин сэтгэлээр гүйцэлдүүлж чаддаг. Тэрээр тэнгэр дэх Бурханыг чин сэтгэлээр шүтэн мөргөж чаддаг бөгөөд Эцэг Бурханы хүслийг үнэн зүрх сэтгэлээсээ эрж хайдаг. Энэ бүгд Түүний мөн чанараар тодорхойлогддог. Иймээс Түүний төрөлхийн илэрхийлэл ч гэсэн мөн чанараар нь тодорхойлогддог; үүнийг “төрөлхийн илэрхийлэл” гэж нэрлэдгийн минь шалтгаан нь Түүний илэрхийлэл бол даган дуурайсан явдал биш, хүний олгосон боловсролын үр дүн ч биш, хүний олон жилийн боловсруулалтын үр дүн ч бас биш. Тэр үүнийг сураагүй, эсвэл Өөрийгөө үүгээр гоёогүй; харин ч энэ нь Түүний дотор төрөлхөөсөө байдаг. Хүн, Түүний ажил, илэрхийлэл, хүн чанар болон хэвийн хүн чанарынх нь бүхий л амьдралыг үгүйсгэж болох боловч тэнгэр дэх Бурханыг үнэн сэтгэлээсээ шүтдэг мөргөдгийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй; тэнгэрлэг Эцэгийн хүслийг биелүүлэхээр ирснийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй, мөн Эцэг Бурханыг эрж хайдаг чин сэтгэлийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй. Хэдий Түүний дүр мэдрэхүйд таатай биш, яриа нь ер бусын өнгө аясгүй, ажил нь хүний төсөөлдөг шиг газар донсолгож, тэнгэр чичрүүлэм биш боловч Тэр бол үнэхээр тэнгэрлэг Эцэгийн хүслийг үнэн сэтгэлээсээ биелүүлж, тэнгэрлэг Эцэгт бүрэн захирагдаж, үхэн үхтэлээ дуулгавартай байдаг Христ мөн юм. Учир нь Түүний мөн чанар бол Христийн мөн чанар билээ. Энэхүү үнэнд хүн итгэхэд хэцүү боловч энэ нь бодит баримт мөн. Христийн үйлчлэл бүрэн гүйцэлдэх үед, Түүний зан чанар болон оршихуй нь тэнгэр дэх Бурханы зан чанар, оршихуйг төлөөлдөг болохыг хүн Түүний ажлаас харж чадна. Тэр үед, Тэрээр үнэхээр махбод болсон Үг мөн бөгөөд мах цуснаас бүрдсэн хүнтэй адилгүй гэдгийг Түүний бүх ажлын нийлбэр цогц баталж чадна. Газар дээрх Христийн ажлын алхам бүр өөрийн гэсэн бэлгэдлийн ач холбогдолтой байдаг боловч алхам бүрийн бодит ажлыг туулдаг хүн Түүний ажлын ач холбогдлыг ухаарч чаддаггүй. Ялангуяа хоёр дахь

удаа бие махбодтой болохдоо Бурханы гүйцэтгэдэг ажлын хэд хэдэн алхмын хувьд ийм байдаг. Христийн үгийг л үзэж дуулснаас биш, Түүнийг хэзээ ч харж байгаагүй ихэнх хүн Түүний ажлын талаар ямар ч үзэлгүй байдаг; Христийг харж, үгийг нь сонссон, мөн ажлыг нь туулсан хүмүүст Түүний ажлыг хүлээн авахад хэцүү байдаг. Христийн гадаад төрх, хэвийн хүн чанар хүнд таалагддаггүй учраас тэр биш үү? Христийг явсны дараа ажлыг нь хүлээн авдаг хүмүүст ийм бэрхшээл гарахгүй, учир нь тэд ердөө л Түүний ажлыг хүлээн авдаг ба Христийн хэвийн хүн чанартай харилцдаггүй. Хүн Бурханы талаарх үзлээ орхиж чаддаггүй, харин ч Түүнийг няхуур судалдаг; энэ нь, хүн Түүний гадаад төрхийг л анхаардгаас биш, ажил болон үгэнд нь үндэслэн Түүний мөн чанарыг таньж чаддаггүйгээс болдог. Хэрвээ хүн Христийн гадаад төрхийг нүдээ анин өнгөрөөж, эсвэл Христийн хүн чанарын талаар ярилцахаас зайлсхийж, ажил болон үгийг нь ямар ч хүн биелүүлэх аргагүй бурханлаг чанарынх нь тухай л ярьдаг бол хүний үзэл хоёр дахин багасаж, бүх бэрхшээл нь шийдвэрлэгдэх хэмжээнд ч хүрнэ. Бие махбодтой болсон Бурханы ажлын үеэр хүн Түүнийг тэвчиж чаддаггүй, Түүний талаарх тоо томшгүй үзлээр дүүрэн байдаг бөгөөд эсэргүүцэж, дуулгаваргүй байх тохиолдол түгээмэл байдаг. Хүн Бурханы оршин тогтнолыг тэвчиж, Христийн номхон даруу, нууцлаг байдлыг хүлцэж, тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагадаг Христийн мөн чанарыг уучилж чаддаггүй. Тиймээс, Тэр ажлаа дуусгасны дараа хүнтэй хамт мөнхөд үлдэж чадахгүй, учир нь хүн Түүнийг өөрсөдтэй нь хамт амьдрахыг зөвшөөрөхийг хүсдэггүй. Хүн Түүнийг ажлынх нь хугацаанд хүлцэж чадахгүй бол үйлчлэлээ хэрэгжүүлчихээд өөрсдийнх нь хажууд амьдарч, Түүний үгийг аажмаар туулахыг нь харахыг хэрхэн тэвчиж чадах билээ? Тэр үед Түүнээс болж олон хүн унахгүй гэж үү? Хүн Түүнд газар дээр ажиллахыг л зөвшөөрдөг; энэ нь хүний хүлцэх хамгийн дээд хязгаар юм. Хэрвээ Түүний ажил байгаагүй бол хүн Түүнийг аль хэдийн газар дэлхийгээс хөөн зайлуулчих байсан, тэгэхээр ажил нь дуусчихвал Түүнд хэчнээн хүлээцгүй хандах билээ? Тэр үед хүн Түүнийг цаазалж, үхтэл нь тамлахгүй гэж үү? Хэрвээ Түүнийг Христ гэдэггүй байсан бол Тэр хүн төрөлхтний дунд ажиллаж чадахгүй байх байсан; хэрвээ Тэр Бурханы Өөрийн ялгамж чанараар ажиллалгүй, ердөө л хэвийн хүн шиг ажилласан бол хүн Түүний ажлын өчүүхэн хэсгийг тэвчих нь байтугай, айлдсан ганц өгүүлбэрийг нь ч тэвчихгүй байх байсан юм. Иймээс Тэр Өөрийнхөө ажилд энэ ялгамж чанараа л авч явах болдог. Ингэхгүй байсныг бодвол, Түүний ажил ийм маягаар илүү хүчирхэг байдаг, учир нь хүмүүс бүгд зэрэг зиндаа, агуу ялгамж чанарыг дуулгавартай дагахыг хүсдэг. Хэрвээ Тэр ажиллахдаа, эсвэл Бурхан Өөрөө болон гарч ирэхдээ Бурханы Өөрийн ялгамж чанарыг авч яваагүй бол, ажил хийх боломж Түүнд огт байхгүй байх байв. Түүнд Бурханы мөн чанар, Христийн оршихуй байдаг хэмээх бодит баримтыг үл харгалзан, хүн Түүнд уужуу сэтгэл гаргаж, хүн төрөлхтний дунд санаа амар ажлаа явуулах боломж олгохгүй байх байв. Тэрээр ажилдаа Бурханы ялгамж чанарыг авч явдаг; хэдийгээр ийм ажил нь, тийм ялгамж чанаргүйгээр хийснээс олон арав дахин

илүү хүчтэй боловч хүн Түүнд одоо ч бүрэн дуулгавартай байдаггүй, учир нь хүн Түүний мөн чанарт биш, зэрэг зиндаанд нь л захирагддаг. Тэгвэл, нэг л өдөр Христ албан тушаалаасаа буувал ганц өдөр ч гэсэн амьд явах боломжийг хүн Түүнд олгох байсан гэж үү? Өөрийн гараар хийсэн ажлаас нь хожмын он жилүүдэд гарах үр нөлөөг харахын тулд Бурхан хүнтэй хамт газар дээр амьдрахыг хүсдэг. Гэвч хүн Түүний байгааг ганц ч өдөр тэвчиж чадахгүй, иймээс Түүнд болихоос өөр арга байхгүй. Хүмүүсийн дунд хийх ёстой ажлаа хийж, Өөрийн үйлчлэлийг хэрэгжүүлэх боломжийг Бурханд олгосон гэдэг нь хэдийнээ хүний хүлээцтэй байдал, нигүүлслийн хамгийн дээд хязгаар билээ. Түүний биечлэн байлдан дагуулсан хүмүүс Түүнд ийм нигүүлсэл үзүүлдэг хэдий ч, нэг ч хором хэтрүүлэлгүй, ажлаа дуустал үлдэхийг л Түүнд зөвшөөрдөг. Тэгвэл Түүний байлдан дагуулаагүй хүмүүс яах вэ? Тэрээр хэвийн хүний бүрхүүлтэй Христ учраас хүн бие махбодтой болсон Бурханд ийм маягаар ханддаг бус уу? Хэрвээ Түүнд хэвийн хүн чанар бус, бурханлаг чанар л байсан бол, хүний бэрхшээлүүд хамгийн хялбархан шийдвэрлэгдэх байсан бус уу? Мөн чанар нь тэнгэрлэг Эцэгийн хүсэлд захирагддаг Христийнх яг мөн байлаа ч гэсэн Түүний бурханлаг чанарыг хүн дурамжхан хүлээн зөвшөөрч, эгэл хүний бүрхүүлийг нь огт сонирхдоггүй. Тийм болохоор Тэр баяр баясгалан, уй гашуугийн аль алийг нь хуваалцахаар хүмүүсийн дунд байх ажлаа цуцлахаас өөр аргагүй болсон, учир нь хүн Түүний оршин тогтнолыг цаашид тэвчиж чадахгүй.

ХҮНИЙ ХЭВИЙН АМЬДРАЛЫГ СЭРГЭЭЖ, ТҮҮНИЙГ ГАЙХАЛТАЙ САЙХАН ХҮРЭХ ГАЗАРТ АВААЧИХ НЬ

Хүн өнөөгийн ажил болон ирээдүйн ажлын тухай бага сага ойлгодог боловч хүн төрөлхтний орох хүрэх газрыг ойлгодоггүй. Бүтээл болохынхоо хувьд хүн бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой: Бурхан юу ч хийлээ гэсэн хүн дагах ёстой ба та нар Миний яв гэсэн замаар явах ёстой. Чамд аливааг өөрөө удирдах ямар ч арга байхгүй бөгөөд чи өөрийгөө хянах чадваргүй; бүгдийг Бурханы эрхшээлд даатгах ёстой бөгөөд бүх зүйл Түүний гарт байдаг. Хэрвээ Бурханы ажил хүнд төгсгөл буюу гайхалтай хүрэх газрыг цагаас нь өмнө өгчихсөн бол, хэрвээ Бурхан үүнийг хүний сэтгэлийг татаж, хүнийг Өөрийнхөө дагагч болгохын тулд ашигласан бол, ингэж Тэрээр хүнтэй наймаацсан бол энэ нь байлдан дагуулалт ч биш, хүний амийн ажил ч биш болох байлаа. Бурхан хүнийг хянаж, зүрх сэтгэлийг нь олж авахын тулд төгсгөлийг ашиглах байсан бол үүгээрээ хүнийг төгс болгохгүй, мөн хүнийг олж авч ч чадахгүй байх байсан, харин ч хүнийг хянахын тулд хүрэх газрыг ашиглаж байгаа явдал болох байв. Хүн ирээдүйн төгсгөл, эцсийн хүрэх газар ба итгэж найдах сайн зүйл байгаа эсэхэд хамгаас их анхаардаг. Хэрвээ байлдан дагуулалтын ажлын явцад хүнд сайхан итгэл найдварыг өгсөн бол, хэрэв хүнийг байлдан

дагуулахаасаа өмнө эрэлхийлбэл зохих хүрэх газрыг нь өгсөн бол хүний байлдан дагуулалт амжилттай үр дүнд хүрэхгүйгээр үл барам, байлдан дагуулалтын ажлын үр дүнд ч мөн нөлөөлөх байсан. Өөрөөр хэлбэл, хүний хувь заяа, хэтийн ирээдүйг булаан авч, хүний тэрслүү зан чанарыг шүүж, гэсгээснээр байлдан дагуулалтын ажил амжилттай үр дүнд хүрдэг. Хүнтэй наймаацаж, өөрөөр хэлбэл хүнд ерөөл, нигүүлсэл өглөө гээд үр дүнгүй, харин хүнийг “эрх чөлөө”-нөөс нь салгаж, хэтийн ирээдүйг нь үгүй хийх замаар хүний үнэнч байдлыг илчилснээр үүнд хүрдэг. Энэ нь байлдан дагуулах ажлын мөн чанар юм. Хэрвээ хүнд бүр эхнээс нь сайхан итгэл найдвар өгөөд, гэсгээлт, шүүлтийн ажлыг дараа нь хийсэн бол өөрт нь хэтийн ирээдүй байгаа гэсэн үндсэн дээр хүн энэхүү гэсгээлт, шүүлтийг хүлээн зөвшөөрөх байсан бөгөөд эцэстээ Бүтээгчийг бүх бүтээл нь болзолгүйгээр дуулгавартай дагаж, шүтэн мөргөхгүй байх байсан; хүн зөвхөн харанхуй, мунхгаар дуулгавартай байж, үгүй бол Бурханд сохроор шаардлага тавих байсан, иймээс хүний зүрх сэтгэлийг бүрэн байлдан дагуулах боломжгүй болох байлаа. Үүний үр дүнд, байлдан дагуулалтын энэ ажлаар хүнийг олж авч чадахгүй, цаашлаад Бурханд гэрчлэл хийх боломжгүй болох байлаа. Ийм бүтээлүүд үүргээ биелүүлж чадахгүй, Бурханд нөхцөл болзол л тавих байсан; энэ нь байлдан дагуулалт бус, харин ердөө л өршөөл, ерөөл байх байв. Хувь заяа, хэтийн ирээдүйгээс өөр юу ч бодолгүй, тэдгээрийг тахин шүтдэг нь хүний хамгийн том асуудал юм. Хүн хувь заяа, хэтийн ирээдүйнхээ төлөө Бурханыг эрэлхийлдэг; Бурханд хайртайдаа Түүнийг шүтэн мөргөдөггүй. Иймээс хүнийг байлдан дагуулахдаа, хүний аминч үзэл, шунал болон Бурханыг шүтэн мөргөхөд нь хамгийн их саад болдог зүйлстэй харьцаж, авч хаяна. Ийнхүү хүний байлдан дагуулалт үр дүнд хүрнэ. Үүний үрээр, хүнийг байлдан дагуулах эхний үе шатанд, хүний жолоогүй хүсэл санаархал болон хамгийн аюултай сул талуудыг арилгаж, үүний дүнд Бурханыг гэх хүний хайрыг илчилж, хүний амьдралын талаарх мэдлэг, Бурханы талаарх үзэл бодол, өөрийнх нь оршин тогтнолын утга учрыг өөрчлөх нь чухал юм. Ийм маягаар Бурханыг гэх хүний хайр цэвэрлэгддэг, өөрөөр хэлбэл, хүний зүрх сэтгэл байлдан дагуулагддаг. Гэвч бүх бүтээлд хандах хандлагадаа Бурхан, байлдан дагуулахын төлөө л байлдан дагуулдаггүй; харин хүнийг олж авахын тулд, Өөрийнхөө алдрын төлөө, мөн хүний хамгийн эртний, анхдагч төрхийг сэргээхийн төлөө байлдан дагуулдаг. Тэр байлдан дагуулахын төлөө л байлдан дагуулдаг байсан бол байлдан дагуулалтын ажлын ач холбогдол алдагдах байлаа. Өөрөөр хэлбэл, Бурхан хүнийг байлдан дагуулсныхаа дараа хэрэгсэхгүй орхиж, түүний амьдрал, үхэлд ямар ч анхаарал хандуулдаггүй байсан бол энэ нь хүн төрөлхтнийг удирдаж байгаа хэрэг биш, хүнийг аврахын төлөө байлдан дагуулсан хэрэг ч биш болох байв. Хүнийг байлдан дагуулсныхаа дараа олж авах, мөн хүн эцэстээ гайхалтай хүрэх газарт очих явдалд л авралын ажлын гол цөм оршдог бөгөөд ингэснээр л хүнийг аврах авралын зорилгод хүрч чадна. Өөрөөр хэлбэл, хүн сайхан хүрэх газарт очиж, амралтад орно гэсэн ийм л хэтийн ирээдүй бүх бүтээлд байх ёстой, энэ л Бүтээгчийн хийх ёстой

ажил юм. Хэрвээ хүн энэ ажлыг хийсэн бол хэтэрхий хязгаарлагдмал болох байлаа: Энэ нь хүнийг тодорхой цэгт аваачиж болох ч мөнхийн хүрэх газарт нь хүргэж чадахгүй байх байв. Хүний хувь заяаг хүн шийдэж чаддаггүй, цаашлаад хүний хэтийн ирээдүй, хожмын хүрэх газрыг ч баталгаажуулж чадахгүй. Харин Бурханы хийдэг ажил бол өөр. Тэрээр хүнийг бүтээсэн тул хүнийг удирдан чиглүүлдэг; Тэр хүнийг авардаг тул бүрмөсөн аварч, бүрэн дүүрэн олж авна; Тэр хүнийг удирдан чиглүүлдэг тул зүй зохистой хүрэх газарт нь аваачна; Тэр хүнийг бүтээсэн, бас удирддаг тул хувь заяа, хэтийн ирээдүйнх нь тухайд хариуцлага хүлээх ёстой. Бүтээгчийн хийдэг ажил энэ юм. Хүнийг хэтийн ирээдүйгээс нь салгаснаар байлдан дагуулалтын ажил биелдэг хэдий ч эцсийн эцэст хүн Бурханы түүнд зориулж бэлдсэн зүй зохистой хүрэх газарт хүргэгдэх ёстой. Бурхан хүнийг бүтээдэг учраас л хүн хүрэх газартай, хувь заяа нь баталгаатай байдаг билээ. Энд хэлж буй тохиромжтой хүрэх газар гэдэг нь хүний өнгөрсөнд устгагдсан итгэл найдвар, хэтийн ирээдүй биш; энэ хоёр нь ондоо юм. Хүний итгэж найдаж, эрэлхийлдэг зүйл нь хүнд тохирсон хүрэх газар бус, харин махан биеийн хэрээс хэтэрсэн хүслээ гүйцээх гэсэн эрэл хайгуулаас улбаатай тэмүүлэл юм. Харин Бурханы хүнд бэлдсэн зүйл бол ариун болгуулсан үед нь хүнд ирэх ерөөл, амлалт бөгөөд Бурхан дэлхий ертөнцийг бүтээснийхээ дараа үүнийг хүнд зориулж бэлтгэсэн, энэ нь хүний сонголт, үзэл, төсөөлөл, махан биеэр бохирдоогүй байдаг. Энэхүү хүрэх газрыг тодорхой нэг хүнд зориулж бэлтгээгүй, харин энэ нь бүх хүн төрөлхтний амралтын газар юм. Иймээс энэ хүрэх газар нь хүн төрөлхтөнд хамгийн тохиромжтой хүрэх газар билээ.

Бүтээгч бүх бүтээлийг зохион байгуулахаар зорьдог. Чи Түүний хийж байгаа аливаа зүйлийг хэрэгсэхгүй орхих юм уу дуулгаваргүй байх ёсгүй, Түүнд тэрслүү хандах ч ёсгүй. Хийж буй ажил нь эцэстээ зорилгодоо хүрэх үед Тэр ийнхүү алдрыг олж авна. Өнөөдөр, чамайг Моабын үр удам, агуу улаан лууны үр сад гэж яагаад хэлэхгүй байна вэ? Яагаад сонгогдсон хүмүүсийн талаар ярихгүй, бүтээлийн талаар л ярьдаг юм бэ? Бүтээл гэдэг нь хүний анхдагч цол байсан, мөн энэ нь түүний төрөлхийн ялгамж чанар юм. Эрин үе болон ажлын мөчлөг өөр учраас л өөр өөр нэр байдаг; үнэндээ хүн бол энгийн бүтээл билээ. Хамгийн ялзарсан нь ч бай, хамгийн ариун нь ч бай хамаагүй, бүх бүтээл бүтээлийн үүргийг биелүүлэх ёстой. Байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэх үедээ Бурхан хэтийн ирээдүй, хувь заяа, хүрэх газрыг чинь ашиглан та нарыг хянадаггүй. Үнэндээ ингэж ажиллах шаардлагагүй. Байлдан дагуулалтын ажлын зорилго нь хүнээр бүтээлийн үүргийг нь гүйцэтгүүлэх, Бүтээгчийг шүтэн мөргүүлэх явдал, үүний дараа л хүн гайхалтай сайхан хүрэх газарт орж чаддаг. Хүний хувь тавилан Бурханы гараар удирдуулдаг. Чи өөрийгөө удирдах чадваргүй: Өөрийнхөө төлөө үргэлж яарч, завгүй байдаг мөртөө хүн өөрийгөө удирдах чадваргүй хэвээр л байдаг. Чи хэтийн ирээдүйгээ мэддэг, заяагаа хянаж чаддаг байсан бол бүтээл хэвээр байх байсан гэж үү? Товчхондоо гэвэл, Бурхан яаж ч ажилладаг бай, Түүний бүх ажил хүний төлөө

байдаг. Жишээлбэл, хүнд үйлчлүүлэхээр Бурханы бүтээсэн тэнгэр, газар, бүх зүйлийг аваад үз: Сар, нар, одыг Тэр хүний төлөө бүтээсэн, амьтан, ургамал, хавар, зун, намар, өвөл гэх зэрэг нь бүгд хүний оршин тогтнолын төлөө бүтээгдсэн байдаг. Иймээс Тэр хүнийг яаж ч гэсгээж, шүүлээ гэсэн, энэ нь бүгд хүний авралын төлөө юм. Тэр хүнийг махан биеийн итгэл найдвараас нь салгадаг хэдий ч энэ нь хүнийг ариусгахын төлөө байдаг бөгөөд хүнийг ариусгадгийн шалтгаан нь түүнийг амьд үлдээхийн төлөө юм. Хүний хувь заяа нь Бүтээгчийн гарт байдаг, иймд хүн өөрийгөө удирдаж яаж чадах юм бэ?

Байлдан дагуулалтын ажил гүйцэлдмэгц хүн үзэсгэлэнтэй сайхан ертөнц рүү хүргэгдэнэ. Энэ амьдрал нь мэдээж газар дээр үргэлжлэх боловч хүний өнөөдрийн амьдралаас шал өөр байх болно. Энэ нь бүх хүн төрөлхтөн байлдан дагуулагдсаны дараах хүн төрөлхтний амьдрал, хүний газар дээрх шинэ эхлэл байх болно, хүн төрөлхтөн ийм амьдралаар амьдарч байгаа нь шинэ, үзэсгэлэнтэй ертөнцөд орсны баталгаа болно. Энэ нь Бурхан болоод хүний газар дээрх амьдралын эхлэл байх болно. Хүн ариусгагдаж, байлдан дагуулагдсаныхаа дараа Бүтээгчийн өмнө захирагдах явдал нь ийм сайхан амьдралын урьдач нөхцөл болох ёстой. Иймээс байлдан дагуулалтын ажил нь хүн төрөлхтөн гайхалтай хүрэх газарт орохын өмнөх, Бурханы ажлын сүүлчийн үе шат юм. Ийм амьдрал нь хүний газар дээрх ирээдүйн амьдрал бөгөөд газар дээрх хамгийн сайхан амьдрал, хүний хүсэмжилдэг төрлийн амьдрал, дэлхийн түүхэнд урьд өмнө нь хүний хэзээ ч хүрч байгаагүй тийм амьдрал билээ. Энэ нь 6,000 жилийн удирдлагын ажлын эцсийн үр дүн, хүн төрөлхтний хамгийн их хүсэн эрмэлздэг зүйл, энэ нь мөн хүнд өгсөн Бурханы амлалт юм. Гэвч энэхүү амлалт нь тэр дороо биелж чаддаггүй: Эцсийн өдрүүдийн ажил дуусаж, хүн бүрэн байлдан дагуулагдсаны дараа, өөрөөр хэлбэл, Сатан бүрмөсөн ялагдсаны дараа л хүн ирээдүйн хүрэх газарт орох болно. Хүн цэвэршүүлэгдсэнийхээ дараа нүгэлт уг чанаргүй байх болно, учир нь Бурхан Сатаныг ялсан байх буюу дайсны хүчний түрэмгийлэл байхгүй болж, хүний махан биед халдаж чадах дайсны хүч үгүй болно гэсэн үг юм. Иймд хүн эрх чөлөөтэй, ариун болно—тэрээр мөнх байдал руу орсон байх болно. Харанхуйн дайсагнасан хүчийг хүлсэн үед л хүн тэрслүү байдал, эсэргүүцэлгүй, хаа ч явсан эрх чөлөөтэй байх болно. Сатан хүлэгдэж байж л хүний бүх зүйл сайн сайхан байх болно; Сатан газар дэлхийн хаа сайгүй төвөг учруулсаар л байгаагаас болж, мөн Бурханы удирдлагын бүхий л ажил хараахан төгсөөгүй байгаа болохоор л одоогийн нөхцөл байдал үүсээд байгаа юм. Сатан ялагдмагц хүн бүрэн чөлөөлөгдөнө; хүн Бурханыг олж авч, Сатаны нөлөөнөөс гарах үедээ зөвт байдлын Нарыг харна. Хэвийн хүнд тохирох амьдрал сэргэнэ; сайн мууг ялган таних чадвар, хэрхэн хооллож, хувцаслах тухай ойлголт болон хэвийн амьдрах чадвар гэх мэт хэвийн хүний эзэмших ёстой бүхэн сэргэнэ. Ева могойд уруу татагдаагүй байсан бол хүн анх бүтээгдсэнийхээ дараа ийм хэвийн амьдралтай байх ёстой байсан. Хүн газар дээр хооллож, хувцаслаж, хэвийн хүний амьдралаар амьдрах ёстой байсан юм. Гэвч хүн доройтолд орсны дараа энэ амьдрал бүтэшгүй

мөрөөдөл болсон бөгөөд өнөөдөр ч гэсэн хүн ийм зүйлийг төсөөлж зүрхэлдэггүй. Үнэндээ, хүний хүсэмжилдэг энэхүү сайхан амьдрал нь зайлшгүй хэрэгцээ юм: Хэрвээ хүнд ийм хүрэх газар байгаагүй бол газар дээрх доройтсон амьдрал нь хэзээ ч дуусахгүй байх байсан, хэрвээ тийм сайхан амьдрал байгаагүй бол Сатаны хувь заяанд, эсвэл газар дээр Сатаны ноёрхдог эрин үед эцэс төгсгөл гэж байхгүй байх байлаа. Харанхуйн хүч хүршгүй ертөнцөд хүн очих ёстой бөгөөд тэр үед Сатан ялагдсан нь батлагдах болно. Ийм маягаар Сатаны тарьдаг үймээн үгүй болмогц Бурхан Өөрөө хүн төрөлхтнийг удирдана, Тэр хүний амьдралыг бүхэлд нь захирч, удирдана; тэр үед л Сатан жинхэнээсээ ялагдсан байх болно. Хүний өнөөдрийн амьдрал нь гол төлөв бохир заваан амьдрал байдаг, энэ нь бас л зовлон зүдүүр, цөхрөлийн амьдрал юм. Үүнийг Сатаны ялагдал гэж нэрлэж болохгүй; хүн цөхрөлийн тэнгисээс, хүний амьдралын бэрхшээл, Сатаны нөлөөллөөс хараахан амь гараагүй байгаа ба Бурханы талаар одоо ч хэтэрхий бага мэдлэгтэй байна. Хүний бүх бэрхшээл Сатанаас үүдэлтэй, Сатан л хүний амьдралд зовлон зүдүүр авчирсан бөгөөд Сатаныг хүлэгдсэний дараа л хүн цөхрөлийн тэнгисээс бүрмөсөн амь гарч чадна. Гэхдээ хүнээр Сатантай хийх тулааны олз омог хийж, хүний зүрх сэтгэлийг байлдан дагуулж, олж авснаар Сатаныг амжилттай хүлдэг.

Өнөөдөр, газар дээр хэвийн хүний амьдралтай болохоосоо өмнө хүн ялагч болж, төгс болгуулахыг эрэлхийлж байдаг бөгөөд Сатаныг хүлэгдэхээс өмнө хүний эрж хайдаг зорилго нь энэ юм. Ялагч болж, төгс болгуулж, их тус хүргэх гэсэн хүний эрэл хайгуул нь мөн чанартаа Сатаны нөлөөнөөс зугтахын төлөө байдаг: Хүний эрэл хайгуул нь ялагч болох явдал боловч эцсийн үр дүнд нь тэр Сатаны нөлөөнөөс мултрах болно. Сатаны нөлөөнөөс мултарснаар л хүн газар дээр Бурханыг шүтэн мөргөдөг, хэвийн хүний амьдралаар амьдарч чадна. Өнөөдөр, ялагч болж, төгс болгуулах гэсэн эрэл хайгуул нь хүний газар дээр хэвийн хүний амьдралтай болохоосоо өмнө эрэлхийлж байдаг зүйлс юм. Үндсэндээ, цэвэрлэгдэж, үнэнийг хэрэгжүүлж, мөн Бүтээгчийг шүтэн мөргөхийн тулд тэдгээрийг эрэлхийлдэг. Хэрвээ хүн газар дээр хэвийн хүний, бэрхшээл, цөхрөлгүй амьдралтай байвал ялагч болох эрэл хайгуул хийхгүй. “Ялагч болох”, “төгс болгуулах” гэдэг нь Бурханы хүнд эрэлхийл гэж өгдөг зорилго бөгөөд эдгээр зорилгын эрэл хайгуулын тусламжтайгаар Тэрээр хүнийг үнэнийг хэрэгжүүлж, утга учиртай амьдралыг амьдран харуулдаг болгодог. Зорилго нь хүнийг бүрэн төгс болгож, олж авах явдал бөгөөд ялагч болох, төгс болгуулах эрэл хайгуул гэдэг бол арга барил төдий юм. Хэрвээ ирээдүйд хүн гайхалтай хүрэх газарт орвол тэнд ялагч болох болон төгс болгуулах тухай огт ярихгүй; тэнд зөвхөн бүтээл бүр үүргээ биелүүлж байх болно. Өнөөдөр, хүнээр эдгээрийг эрэлхийлүүлж байгаа нь ердөө л хүний эрх хэмжээг тодорхойлохын тулд бөгөөд, ингэснээр хүний эрэл хайгуул нь илүү зорилттой бөгөөд бодитой байж чадах юм. Эс бөгөөс, хүн тодорхойгүй хийсвэр байдалд амьдарсаар, мөнх амь руу орохоор эрэлхийлэх байсан, тэгсэн бол хүн улам ч өрөвдөлтэй байх байсан биш гэж үү? Зорилго ч үгүй, зарчим ч үгүй, ийм маягаар

эрэлхийлэх нь өөрийгөө хуурсан хэрэг биш гэж үү? Эцсийн эцэст энэ эрэл хайгуул нь угаасаа үр өгөөжгүй байх байв; эцэст нь хүн Сатаны эзэмшил дор амьдарсаар л, өөрийгөө тэндээс чөлөөлөх чадалгүй байх байв. Яагаад ийм зорилгогүй эрэл хайгуулд өөрийгөө зүтгүүлнэ вэ? Хүн мөнхийн хүрэх газарт орох үедээ Бүтээгчийг шүтэн мөргөнө, хүн аврал олж авч, мөнх байдалд орсон учраас ямар нэг зорилгыг эрэлхийлэхгүй, цаашлаад Сатанд бүслэгдэх вий гэж санаа зовох хэрэггүй болно. Энэ үед хүн байх байраа мэдэж, үүргээ биелүүлэх бөгөөд гэсгээгдэж, шүүгдээгүй байсан ч гэсэн хүн бүр үүргээ биелүүлж байх болно. Тэр үед хүн ялгамж чанар, байр суурийнхаа аль алины хувьд бүтээл байх болно. Дээд, доодын ялгаа гэж цаашид байхаа болино; хүн бүхэн зүгээр л өөр өөр чиг үүрэг гүйцэтгэх болно. Гэсэн ч хүн мөн л дэг журамтай, хүн төрөлхтөнд тохиромжтой хүрэх газарт амьдарч байх болно, хүн Бүтээгчийг шүтэн мөргөхийн төлөө үүргээ биелүүлнэ, тэгээд ийм хүн төрөлхтөн нь үүрд мөнхийн хүн төрөлхтөн болох болно. Тэр үед хүн Бурханы гэрэлтүүлсэн амьдралыг, Бурханы халамж, хамгаалалт доорх амьдралыг, Бурхантай хамт байх амьдралыг олж авсан байх болно. Хүн төрөлхтөн газар дээр хэвийн амьдралаар амьдарч, бүх хүн зөв замд орно. 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөө нь Сатаныг бүрэн дүүрэн ялчихсан байх болно, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрийнхөө бүтээл дээр хүний анхдагч дүрийг сэргээсэн байх болно, ингэснээр Бурханы анхдагч санаа зорилго биелсэн байх болно. Анх Сатаныг ялзруулахаас өмнө хүн төрөлхтөн газар дээр хэвийн амьдралаар амьдарч байсан. Дараа нь Сатаныг ялзруулах үед хүн хэвийн амьдралаа алдсан, ийнхүү Бурханы удирдлагын ажил болон хүний хэвийн амьдралыг сэргээхийн төлөө Сатантай хийх тулаан эхэлсэн. Бурханы 6,000 жилийн удирдлагын ажил төгсгөл болох үед л бүх хүн төрөлхтний амьдрал газар дээр албан ёсоор эхэлнэ, тэр үед л хүн гайхалтай амьдралтай болох ба анх хүнийг бүтээсэн зорилгоо болон хүний анхдагч төрхийг Бурхан сэргээнэ. Иймээс газар дээрх хэвийн хүн төрөлхтний амьдралтай болмогцоо хүн ялагч болох юм уу төгс болгуулахаар эрэлхийлэхгүй, учир нь хүн ариун байх болно. Хүмүүсийн ярьдаг “ялагчид”, “төгс болгуулах” гэдэг нь Бурхан, Сатан хоёрын тулааны үеэр хүнийг эрэлхийл гэж өгсөн зорилго бөгөөд хүн ялзарсан учраас л тэдгээр нь оршдог. Чамд зорилго өгч, чамайг тэрхүү зорилгыг эрэлхийлэхэд хүргэснээр Сатан ялагдах болно. Ялагч байж, төгс болгуулж, хэрэгтэй хүн байхыг чамаас хүсдэг нь Сатаныг шившиглэхийн тулд гэрчлэл хийхийг чамаас шаардаж байгаа хэрэг юм. Эцэстээ хүн газар дээр хэвийн хүний амьдралаар амьдарч, ариун байх бөгөөд ийм зүйл тохиолдох үед тэд бас л ялагч болохоор эрж хайна гэж үү? Тэд бүгд бүтээл биш гэж үү? Ялагч байх, төгс болгуулсан нэгэн байх тухайд ярихад, эдгээр үг нь Сатан руу болон хүний бохир заваан байдал руу чиглэсэн байдаг. Энэхүү “ялагч” гэдэг нь Сатаныг болон дайсны хүчийг ялахтай холбоогүй гэж үү? Чи өөрийгөө төгс болгуулсан гэж хэлэх үед чиний доторх юу төгс болгуулсан байдаг юм бэ? Чи Бурханыг гэх дээдийн дээд хайранд хүрэхийн тулд ялзарсан сатанлаг зан чанараасаа ангижирсан бус уу? Ийм зүйлсийг хүний доторх бохир заваан зүйлс

болон Сатантай холбогдуулан хэлдэг; Бурхантай хамаатуулж хэлдэггүй.

Өнөөдөр чи ялагч болж, төгс болгуулахаар эрэлхийлэхгүй бол ирээдүйд хүн төрөлхтөн газар дээр хэвийн амьдралаар амьдрах үед ийм эрэл хайгуул хийх завшаан гарахгүй. Тэр үед бүх төрлийн хүний төгсгөл илчлэгдсэн байх болно. Тэр үед ямар төрлийн зүйл вэ гэдэг чинь тодорхой болно, тэгээд чи ялагч болох юм уу төгс болгуулахыг хүсвэл тэгэх боломжгүй байх болно. Зөвхөн хүн тэрслүү байдлынхаа төлөө илчлэгдсэнийхээ дараа шийтгэгдэнэ. Тэр үед хүн бусдаасаа дээгүүр байр суурийг эрэлхийлэхгүй, зарим нь ялагч болох, бусад нь төгс болгуулах, өөр зарим нь Бурханы ууган хөвгүүд байх, бусад нь Бурханы хөвгүүд байх зэргээр тэд эрэлхийлэхгүй; эдгээр зүйлийг тэд эрэлхийлэхгүй. Бүгд Бурханы бүтээл байж, бүгд газар дээр амьдарна, тэгээд бүгд газар дээр Бурхантай хамт амьдрах болно. Одоо үе бол Бурхан, Сатан хоёрын тулааны цаг үе, энэхүү тулаан хараахан дуусах болоогүй цаг үе, хүнийг хараахан бүрэн олж аваагүй байгаа цаг үе бөгөөд шилжилтийн үе юм. Иймээс хүнээс ялагч юм уу Бурханы ардын нэг болохоор эрэлхийлэхийг шаарддаг. Өнөөдөр байр сууринд ялгаа байдаг боловч цаг нь ирэхээр ийм ялгаа үгүй болно: Ялалт байгуулсан бүх хүний байр суурь адилхан байх болно, тэд бүгд шаардлага хангасан хүн төрөлхтөн байх бөгөөд газар дээр эрх тэгш амьдарна, өөрөөр хэлбэл, тэд бүгд шаардлага хангасан бүтээл байж, бүгдэд ав адилхан зүйл өгөгдөнө гэсэн үг юм. Бурханы ажлын эрин үеүд өөр өөр, ажлынх нь бай ч бас өөр өөр байдаг учраас хэрвээ энэхүү ажлыг та нар дээр хийсэн бол та нар төгс болгуулж, ялагч болох эрхтэй; хэрвээ хилийн чанадад хийсэн байсан бол тэндхийн хүмүүс байлдан дагуулагдах эхний бүлэг хүмүүс, мөн төгс болгуулах эхний бүлэг хүмүүс болох эрхтэй байх байсан. Өнөөдөр энэ ажлыг хилийн чанадад хийдэггүй, иймээс тэд төгс болгуулж, ялагчид болох эрхгүй бөгөөд эхний бүлэг хүмүүс болох боломжгүй юм. Бурханы ажлын бай өөр, Бурханы ажлын эрин үе өөр, үүний хамрах хүрээ өөр учраас эхний бүлэг буюу ялагчид гэж байдаг шиг төгс болгуулсан хоёр дахь бүлэг ч бас байх болно. Эхний бүлэг төгс болгуулмагц үлгэр дуурайл, загвар бий болно, ингээд ирээдүйд төгс болгуулах хүмүүсийн хоёр, гурав дахь бүлэг гарах боловч мөнхөд тэд бүгд адилхан байх ба байр суурийн ямар ч ангилал гарахгүй. Тэд ердөө л өөр өөр цаг үед төгс болгуулсан байх бөгөөд байр суурь нь ямар ч ялгаагүй байх болно. Хүн бүхэн бүрэн төгс болгуулж, бүхий л орчлон ертөнцийн ажил дууссан байх цаг ирэх үед байр суурийн ялгаа гэж үгүй байх ба бүгд эрх тэгш байр суурьтай байх болно. Өнөөдөр та нарыг ялагч болгох гэж энэ ажлыг та нарын дунд хийдэг. Хэрвээ үүнийг Британид хийсэн бол та нар эхний бүлэг болгуулахтай адилаар Британи эхний бүлэг болох байсан. Өнөөдөр та нар дээр ажил хийж байгаа нь ердөө нигүүлслээр ерөөж байгаа хэрэг бөгөөд хэрвээ энэ ажлыг та нар дээр хийгээгүй бол та нар хоёр, гурав, дөрөв, тав дахь бүлэг болох байсан. Энэ нь зүгээр л ажлын дэс дараалал дахь ялгаанаас үүдэлтэй; эхний бүлэг, хоёр дахь бүлэг гэдэг нь нэг нь нөгөөгөөсөө дээр, доор байгааг заадаггүй, ердөө л хүмүүсийн төгс болгуулсан дарааллыг заадаг. Өнөөдөр

эдгээр үгийг та нарт хэлж байна, гэхдээ яагаад та нарт арай эртхэн мэдэгдээгүй юм бэ? Учир нь, үйл явцгүйгээр хүмүүс туйлшрах хандлагатай байдаг. Жишээлбэл, Есүс тухайн үед: “Би явсан шигээ ирэх болно” гэж хэлсэн. Өнөөдөр олон хүн энэ үгэнд ухаанаа алдаж, цагаан нөмрөг өмсөн, тэнгэр лүү өргөгдөхөө хүлээхийг л хүсдэг. Тиймээс хэтэрхий эрт хэлж болохгүй олон үг байдаг; хэрвээ хэтэрхий эрт хэлчихвэл хүн туйлшрах хандлага гаргана. Хүний биеийн хэмжээ хэтэрхий жижиг бөгөөд эдгээр үгийн бодит үнэнийг нэвт харах чадваргүй байдаг.

Хүн газар дээр жинхэнэ хүний амьдралтай болж, Сатаны бүхий л хүч хүлэгдэх үед тэр газар дээр амар хялбар амьдарна. Аливаа зүйл өнөөдрийнх шигээ ярвигтай байхгүй: Хүний харилцаа, нийгмийн харилцаа, гэр бүлийн төвөгтэй харилцаа—эдгээр нь маш их хүндрэл бэрхшээл, зовлон учруулдаг! Хүний энэ амьдрал үнэхээр золгүй! Хүн байлдан дагуулагдмагц зүрх сэтгэл, оюун санаа нь өөрчлөгдөнө: Тэр Бурханыг хүндэлдэг, Бурханыг хайрладаг зүрх сэтгэлтэй болно. Орчлон ертөнц дээрх Бурханыг хайрлахаар эрж хайдаг бүхэн байлдан дагуулагдмагц, өөрөөр хэлбэл, Сатан ялагдаж, Сатан буюу харанхуйн бүх хүч хүлэгдмэгц газар дээрх хүний амьдрал хүндрэл бэрхшээлгүй болох ба хүн газар дээр эрх чөлөөтэй амьдарч чадна. Хэрвээ хүний амьдралд махан биеийн харилцаа байдаггүй, махан биеийн ярвигтай байдал байдаггүй байсан бол хамаагүй амар байх байлаа. Хүний махан биеийн харилцаа нь хэтэрхий ярвигтай бөгөөд хүнд тийм зүйлс байгаа нь тэр өөрийгөө Сатаны нөлөөллөөс хараахан чөлөөлөөгүй гэдгийн нотолгоо юм. Хэрвээ чи ах эгч нар болгонтойгоо адилхан харилцаатай, гэр бүлийн гишүүн бүртэйгээ адилхан харилцаатай байсан бол санаа зовних юмгүй, хэний ч талаар сэтгэлээ зовоох хэрэггүй байх байсан. Үүнээс дээр зүйл гэж үгүй ба энэ маягаар хүн зовлон шаналлынхаа хагасыг хөнгөлөх байв. Газар дээр хэвийн хүний амьдралаар амьдарснаар, хүн тэнгэрэлчтэй төстэй байх болно; махан биетэй хэвээр боловч хүн тэнгэрэлчтэй тун адилхан байх болно. Энэ бол сүүлчийн амлалт, хүнд хайрласан эцсийн амлалт юм. Өнөөдөр хүн гэсгээлт, шүүлтийг туулдаг; хүн ийм зүйлсийг туулах нь утга учиргүй гэж чи боддог уу? Гэсгээлт, шүүлтийн ажлыг ямар ч шалтгаангүйгээр хийж болох уу? Хүнийг гэсгээж, шүүнэ гэдэг нь түүнийг ёроолгүй нүхэнд оруулах явдал юм гэж өмнө нь хэлсэн, энэ нь хүний хувь заяа, хэтийн ирээдүйг булаан авна гэсэн утгатай. Энэ нь ганцхан хүнийг цэвэрлэхийн төлөө байдаг. Хүнийг зориудаар ёроолгүй нүхэнд оруулсны дараа Бурхан түүнийг хэрэгсэхгүй орхидог хэрэг биш. Харин ч энэ нь хүний доторх тэрслүү байдалтай харьцахын төлөө байдаг, ингэснээр эцэстээ хүний доторх зүйлс цэвэрлэгдэж, хүн Бурханы тухай жинхэнэ мэдлэгтэй болж, ариун хүн шиг болох болно. Энэ биелбэл бүгд гүйцэлдэх нь тэр. Үнэндээ, хүний доторх харьцах учиртай тэдгээр зүйлтэй харьцаж, хүн цангинасан гэрчлэл хийх үед Сатан ч бас ялагдана, хүний дотор анхнаасаа байдаг тэдгээр зүйл бүрэн цэвэрлэгдээгүй байж болох ч Сатаныг ялагдмагц эдгээр нь цаашид төвөг учруулахгүй ба тэр үед хүн бүрэн цэвэрлэгдсэн байх болно. Хүн хэзээ ч ийм амьдрал туулж байгаагүй, гэхдээ Сатаныг ялагдах үед бүх зүйл зохицуулагдаж,

хүний доторх тэдгээр ялихгүй зүйл бүгд шийдэгдэнэ; үндсэн асуудал шийдвэрлэгдмэгц бусад бүх бэрхшээл эцэс болно. Бурхан хүмүүсийн дунд ажлаа өөрийн биеэр хийж буй, газар дээр бие махбодтой болсон энэ хугацаанд Түүний хийж байгаа бүх ажил нь Сатаныг ялахын төлөө байдаг бөгөөд хүнийг байлдан дагуулж, та нарыг бүрэн төгс болгох замаар Тэр Сатаныг ялах болно. Та нар цангинасан гэрчлэл хийх үе ч гэсэн Сатаны ялагдлын тэмдэг байх болно. Сатаныг ялахын тулд хүн эхлээд байлдан дагуулагдаж, эцэстээ бүрмөсөн төгс болгуулдаг. Гэхдээ мөн чанартаа энэ нь Сатаны ялагдлын зэрэгцээ бүх хүн төрөлхтнийг цөхрөлийн энэ хоосон тэнгисээс аварч буй аврал юм. Энэхүү ажил бүхий л орчлон ертөнц даяар явагддаг уу, Хятадад явагддаг уу гэдгээс үл хамааран бүх ажил нь Сатаныг ялж, бүхий л хүн төрөлхтөнд аврал авчрахын төлөө байдаг бөгөөд ингэснээр хүн амралтын газарт орох боломжтой болно. Бие махбодтой болсон Бурхан буюу энэхүү хэвийн махбод чухамдаа Сатаныг ялахын төлөө оршдог. Бие махбодтой Бурханы ажлыг тэнгэрийн доорх, Бурханыг хайрладаг бүх хүнд аврал авчрахад ашигладаг, энэ нь бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулахын төлөө, цаашлаад Сатаныг ялахын төлөө байдаг. Бурханы бүх удирдлагын ажлын гол цөм нь бүх хүн төрөлхтөнд аврал авчрахын тулд Сатаныг ялахтай салшгүй холбоотой. Яагаад энэ ажлын үеэр ихэнхдээ та нараар гэрчлэл хийлгэх тухай ярьдаг вэ? Энэ гэрчлэл нь хэнд чиглэдэг вэ? Сатан руу чиглэдэггүй гэж үү? Энэ гэрчлэлийг Бурханд хийдэг, Бурханы ажил үр дүндээ хүрсэн гэдгийг гэрчлэхийн тулд хийдэг. Гэрчлэл хийх нь Сатаныг ялах ажилтай холбоотой; Сатантай хийх тулаан гэж байгаагүй бол гэрчлэл хийхийг хүнээс шаардахгүй байх байсан. Хүнийг аврахын зэрэгцээ Сатаныг ялах ёстой учраас Өөрийг нь Сатаны өмнө гэрчлэхийг Бурхан хүнээс шаарддаг, үүнийг хүнийг аварч, Сатантай тулалдахдаа ашигладаг. Үүний үр дүнд, хүн авралын бай, Сатаныг ялах хэрэгслийн аль аль нь болдог, иймээс хүн Бурханы бүхий л удирдлагын ажлын цөм нь байдаг бол Сатан ердөө л дайсан бөгөөд сүйрлийн бай юм. Чамд чи юу ч хийгээгүй мэт санагдаж болох юм, гэхдээ чиний зан чанар дахь өөрчлөлтийн улмаас гэрчлэл бий болсон бөгөөд энэ гэрчлэл нь Сатан руу чиглэдэг ба хүнд зориулагддаггүй. Хүн ийм гэрчлэлийг эдлэхэд тохирохгүй. Бурханы хийсэн ажлыг хүн яаж ойлгож чадах юм бэ? Бурханы тэмцлийн бай нь Сатан; харин хүн бол зөвхөн авралын бай юм. Хүн ялзарсан сатанлаг зан чанартай бөгөөд энэ ажлыг ойлгох чадваргүй. Энэ нь Сатаны завхралаас болдог бөгөөд хүний төрөлх чанар биш, харин үүнийг Сатан чиглүүлдэг. Өнөөдөр Бурханы үндсэн ажил бол Сатаныг ялах, өөрөөр хэлбэл, хүнийг бүрмөсөн байлдан дагуулах явдал, ингэснээр хүн Сатаны өмнө Бурханд эцсийн гэрчлэлийг хийж, ийм маягаар бүх зүйл гүйцэлдэх болно. Олон тохиолдолд, чиний энгийн нүдэнд юу ч хийгдээгүй мэт харагддаг боловч үнэндээ ажил аль хэдийн дууссан. Биелсэн бүх ажил харагдахуйц байхыг хүн шаарддаг, гэсэн ч Би чамд ил болголгүйгээр ажлаа дуусгасан, учир нь Сатан захирагдсан, өөрөөр хэлбэл, Сатан бүрмөсөн ялагдаж, Бурханы бүх мэргэн ухаан, хүч чадал, эрх мэдэл Сатаныг ялсан

билээ. Хийгдэх ёстой гэрчлэл нь яг энэ бөгөөд хүн дээр тодорхой илэрдэггүй ч, энгийн нүдээр харагддаггүй ч Сатан аль хэдийн ялагдсан. Энэ ажил бүхэлдээ Сатаны эсрэг чиглэж, Сатантай хийх тулааны улмаас хэрэгжсэн юм. Иймээс хүний амжилттай болсон гэж хардаггүй олон зүйл байдаг ч Бурханы нүдээр бол аль эрт амжилттайгаар дуусгавар болсон байдаг. Энэ нь Бурханы бүх ажлын дотоод бодит үнэний нэг билээ.

Сатаныг ялагдмагц буюу хүнийг бүрэн байлдан дагуулмагц, энэ бүх ажил нь авралын төлөө гэдгийг, энэхүү авралын арга зам нь Сатаны гараас хүмүүсийг булаан авах явдал гэдгийг хүн ойлгоно. Бурханы 6,000 жилийн удирдлагын ажил нь Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе ба Хаанчлалын эрин үе гэсэн гурван үе шатанд хуваагддаг. Ажлын энэ гурван үе шат нь бүгд хүн төрөлхтний авралын төлөө, өөрөөр хэлбэл, Сатаны асар их ялзруулсан хүн төрөлхтнийг аврахын төлөө байдаг. Гэхдээ бас үүний зэрэгцээ эдгээр нь Бурханы Сатантай хийх тулааны төлөө байдаг. Тиймээс авралын ажил гурван үе шатанд хуваагддагийн адилаар Сатантай хийх тулаан ч мөн гурван үе шатанд хуваагдаж, Бурханы ажлын энэ хоёр тал нэгэн зэрэг явагддаг. Сатантай хийх тулаан нь үнэндээ хүн төрөлхтний авралын төлөө байдаг бөгөөд хүн төрөлхтний авралын ажил нь ганцхан үе шатанд амжилттай дуусгаж болох зүйл биш тул Сатантай хийх тулаан ч гэсэн шатлал, мөчлөгт хуваагдаж, хүний хэрэгцээ, Сатаны ялзруулсан хэмжээний дагуу Сатантай дайн хийгддэг. Хоёр арми хоорондоо тулалддагийн адилаар Бурхан энэ тулаанд Сатаны эсрэг зэвсгээр байлдах болно гэж хүн төсөөлөлдөө боддог байх. Хүний оюун ухаан ингэж л төсөөлөх чадвартай ба туйлын тодорхойгүй, хийсвэр санаа хэдий ч хүн ингэж л итгэдэг. Хүнийг аврах арга зам нь Сатантай хийх тулаанаар дамждаг гэж Намайг энд хэлсэн учраас тулаан ингэж явагддаг гэж хүн төсөөлдөг. Хүний авралын ажилд гурван үе шат байдаг, өөрөөр хэлбэл, Сатантай хийдэг тулаан нь Сатаныг нэгмөсөн ялахын тулд гурван үе шатанд хуваагддаг гэж хэлж болно. Гэвч Сатантай тулалдах бүхий л ажлын дотоод үнэн нь хүнд нигүүлсэл хайрлах, хүний нүглийн тахил болох, хүний нүглийг уучлах, хүнийг байлдан дагуулах, хүнийг төгс болгох гэсэн ажлын хэд хэдэн алхмаар дамжин үр дүнд хүрдэгт оршдог. Үнэндээ Сатантай хийх тулаан нь Сатаны эсрэг зэвсгээр байлдах бус, харин хүний аврал, хүний амийн ажил болон хүний зан чанарыг өөрчилснөөр хүн Бурханд гэрчлэл хийх боломжтой болох явдал юм. Сатан ингэж ялагддаг. Хүний ялзарсан зан чанарыг өөрчлөх замаар Сатаныг ялдаг. Сатан ялагдсан үед буюу хүн бүрэн аврагдсан үед шившиглэгдсэн Сатан бүрэн хүлэгдэх болно, энэ маягаар хүн бүрэн аврагдсан байх болно. Иймээс хүний авралын мөн чанар нь Сатантай хийх тулаан бөгөөд хүний аврал нь үндсэндээ энэ дайны тусгал болдог. Хүнийг байлдан дагуулах эцсийн үе шат нь Сатантай хийх тулааны сүүлчийн үе шат төдийгүй Сатаны эзэмшлээс хүнийг бүрэн аврах ажил юм. Хүнийг байлдан дагуулахын дотоод утга учир нь, Сатаны биелэл болсон Сатаны ялзруулсан хүн байлдан дагуулагдсаныхаа дараа Бүтээгч рүү эргэн очих явдал бөгөөд үүгээр дамжуулан тэр Сатаныг хаяж,

Бурхан руу бүрмөсөн буцаж очно. Ийм замаар хүн бүрэн аврагдсан байх болно. Иймээс байлдан дагуулалтын ажил нь Сатаны эсрэг тулааны сүүлчийн ажил бөгөөд Сатаныг ялахын төлөөх Бурханы удирдлагын эцсийн үе шат юм. Энэ ажилгүйгээр хүний бүрэн аврал эцсийн дүндээ боломжгүй болно, Сатаныг бүрэн ялах ч боломжгүй болж, хүн төрөлхтөн хэзээ ч гайхалтай хүрэх газарт орж, Сатаны нөлөөнөөс чөлөөлөгдөж чадахгүй байх байсан юм. Үүний үр дүнд, Сатантай хийх тулаан дуусахаас нааш хүнийг аврах ажил дуусна гэж байхгүй, учир нь Бурханы удирдлагын ажлын цөм нь хүн төрөлхтний авралын төлөө байдаг. Хамгийн эртний хүн төрөлхтөн Бурханы гарт байсан боловч Сатаны уруу таталт, ялзралын улмаас хүн Сатанд хүлэгдэж, ёрын муу нэгний гарт орсон. Тиймээс Бурханы удирдлагын ажлын ялах учиртай бай нь Сатан болсон юм. Сатан хүнийг эрхшээлдээ оруулсан учраас, мөн хүн бол Бурханы бүх удирдлагаа хэрэгжүүлэхдээ ашигладаг хөрөнгө учраас хүнийг аваръя гэвэл түүнийг Сатаны гараас эргүүлээд булаах ёстой, өөрөөр хэлбэл, Сатанд олзлогдсон байсан хүнийг буцаан олж авах ёстой гэсэн үг. Тиймээс, хүний хуучин зан чанарын өөрчлөлт, анхдагч эрүүл ухааныг нь сэргээх өөрчлөлтөөр дамжуулан Сатаныг ялах ёстой. Ийм маягаар, олзлогдсон хүнийг Сатаны гараас эргүүлээд булаан авч болно. Хэрвээ хүнийг Сатаны нөлөө болон хүлээснээс чөлөөлбөл Сатан шившиг болж, эцсийн эцэст хүнийг буцаан олж авч, Сатан ялагдах болно. Сатаны харанхуй нөлөөнөөс чөлөөлөгдсөн учраас хүн энэ бүх тулааны олз омог болж, Сатан нь энэ тулаан дуусмагц шийтгэгдэх бай болно, үүний дараа хүн төрөлхтнийг аврах бүхий л ажил дууссан байх болно.

Бурхан бүтээлүүдэд ямар ч өс санадаггүй ба Сатаныг ялахыг л хүсдэг. Гэсгээлт ч бай, шүүлт ч бай, Түүний бүх ажил Сатан руу чиглэдэг; үүнийг хүн төрөлхтний авралын төлөө хийдэг, энэ нь бүгд Сатаныг ялахын төлөө бөгөөд эцсийг нь үзтэл Сатантай тулалдах гэсэн нэг л зорилготой байдаг! Сатаныг ялж байж л Тэр амрах болно. Бурханы хийдэг бүх ажил Сатан руу чиглэдэг учраас, мөн Сатаны ялзруулсан хүмүүс бүгд Сатаны эзэмшлийн хяналтад, Сатаны эзэмшил дор амьдардаг учраас Сатаны эсрэг тулалдаж, түүнээс ангижрахгүй л бол Сатан энэ хүмүүсийг тавихгүй ба хүмүүс авхуулж чадахгүй байх байсан. Тэд авхуулаагүй бол энэ нь Сатан ялагдаагүй, дийлдээгүй гэдгийг нотлох байсан. Иймээс Бурханы 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөнд, эхний үе шатанд нь Тэр хуулийн ажил хийж, хоёр дахь үе шатанд нь Нигүүлслийн эрин үеийн ажил буюу цовдлолын ажил хийж, гурав дахь үе шатанд нь хүн төрөлхтнийг байлдан дагуулах ажил хийсэн. Энэ бүх ажил нь Сатаны хүн төрөлхтнийг ялзруулсан хэмжээ рүү чиглэдэг, энэ нь бүгд Сатаныг ялахын тулд, үе шат бүр нь Сатаныг ялахын төлөө байдаг. Бурханы 6,000 жилийн удирдлагын ажлын мөн чанар нь агуу улаан лууны эсрэг тулаан бөгөөд хүн төрөлхтнийг удирдах ажил бол мөн Сатаныг ялах ажил, Сатантай тулаан хийх ажил юм. Бурхан 6,000 жилийн турш тулалдаж, эцэстээ хүнийг шинэ ертөнцөд аваачихын тулд 6,000 жилийн турш ийнхүү ажилласан. Сатан ялагдсан үед хүн бүрэн чөлөөлөгдөнө. Өнөөдрийн Бурханы ажлын чиглэл энэ биш гэж үү? Хүнийг

бүрэн чөлөөлж, сулласнаар хүн ямар ч дүрэмд захирагдахгүй, ямар ч хүлээс, хоригт хязгаарлагдахгүй байх явдалд чухамдаа өнөөдрийн ажил чиглэдэг юм. Энэ бүх ажил нь та нарын биеийн хэмжээ болон хэрэгцээний дагуу хийгддэг, өөрөөр хэлбэл, хэрэгжүүлж чадах зүйлийг чинь л та нарт өгдөг. Энэ нь та нарт ямар нэгэн зүйл тулгаж, “хэрээс чинь хэтэрсэн зүйл даалгаж буй” хэрэг биш; харин ч энэ бүх ажил бодит хэрэгцээний чинь дагуу явагддаг. Ажлын үе шат болгон нь хүний бодит хэрэгцээ, шаардлагын дагуу, мөн Сатаныг ялахын төлөө байдаг. Үнэндээ, анх Бүтээгч болон Түүний бүтээлүүдийн хооронд ямар ч саад тотгор байгаагүй. Саад тотгор бүхнийг Сатан учруулсан. Сатаны учруулсан үймээн, ялзралын улмаас хүн юуг ч харж, юунд ч хүрч чадахаа больсон. Хүн бол хохирогч, хууртсан нэгэн билээ. Сатан ялагдмагц бүтээлүүд Бүтээгчийг харна, мөн Бүтээгч бүтээлүүдээ харах ба тэднийг биечлэн удирдаж чадна. Энэ нь л газар дээр хүнд байх ёстой амьдрал юм. Иймээс Бурханы ажил үндсэндээ Сатаныг ялахын төлөө байдаг бөгөөд Сатаныг ялагдмагц бүх зүйл шийдвэрлэгдэх болно. Бурхан хүмүүсийн дунд ирнэ гэдэг нь энгийн нэг хэрэг биш гэдгийг өнөөдөр чи харлаа. Өдөр хоногийг та нараас алдаа зөрчил олоход зориулж, ийм тийм гэж хэлэх гэж, эсвэл зүгээр л Өөрийнхөө ямар харагддаг, мөн яаж хэлж ярьж, ямаршуухан амьдардгийг та нарт харуулах гэж Тэр ирээгүй. Бурхан та нарт Өөрийг нь харах боломж олгох гэж, та нарын нүдийг нээх гэж, эсвэл Өөрийн хэлсэн нууц болон Өөрийн нээсэн долоон лацыг та нарт сонсгох гэж л махбод болоогүй. Харин Тэр Сатаныг ялах гэж махбод болсон. Тэр хүнийг аварч, Сатантай тулалдахын тулд хүмүүсийн дунд махбодтойгоор биечлэн ирсэн бөгөөд Түүний бие махбодтой болдгийн ач холбогдол энэ билээ. Сатаныг ялахын тулд л биш бол энэ ажлыг Тэр биечлэн хийхгүй байх байсан. Бурхан хүмүүсийн дунд ажлаа хийж, Өөрийгөө хүнд биечлэн илчилж, Өөрийг нь харах боломжийг хүнд олгох гэж газар дээр ирсэн; энэ шалихгүй асуудал гэж үү? Энэ бол үнэхээр энгийн нэг хэрэг биш! Хүний төсөөлдөг шигээр, Бурхан хүнд харагдах гэж, мөн тодорхойгүй, хий хоосон биш, харин бодитой гэдгээ, өндөр дээд атлаа даруу гэдгээ хүнд ойлгуулах гэж ирдэг юм биш. Ийм энгийн байж болно гэж үү? Сатан хүний махан биеийг ялзруулсан учраас, мөн Бурханы аврахаар зорьдог нэгэн нь хүн учраас л чухамдаа Бурхан Сатантай тулалдаж, хүнийг биечлэн хариулахын тулд махбодтой болох ёстой болсон. Энэ нь л Түүний ажилд ашиг тустай юм. Сатаныг ялж, хүнийг илүү сайн аврахын тулд Бурханы хоёр удаа махбод болсон бие оршин байдаг. Учир нь, Бурханы Сүнс байна уу, Бурханы махбод болсон бие байна уу хамаагүй Сатантай тулалддаг нэгэн нь Бурхан л байж чадна. Товчхондоо гэвэл, Сатантай тулалддаг нэгэн нь тэнгэрэлч байж болохгүй, Сатаны ялзруулсан хүн байж бүр ч болохгүй. Тэнгэрэлчүүд үүнийг хийх хүч чадалгүй бол хүн бүр ч хүчин мөхөс. Ийм болохоор, хэрвээ Бурхан хүний амийг боловсруулахыг хүсвэл, мөн хүнийг аврахаар газар дээр биечлэн ирэхийг хүсвэл Өөрийн биеэр махбод болох ёстой, өөрөөр хэлбэл, Тэрээр биечлэн махбодтой болж, төрөлхийн ялгамж чанар, хийх ёстой ажлынхаа хамтаар хүмүүсийн дунд ирж, хүнийг биечлэн аврах ёстой.

Ингэлгүй, энэ ажлыг Бурханы Сүнс юм уу хүн хийсэн бол энэ тулаан ямар ч үр дүнд хүрэхгүй, хэзээ ч төгсөхгүй байсан билээ. Сатаны эсрэг дайнд Өөрийн биеэр явахын тулд Бурхан хүмүүсийн дунд махбод болсон үед л хүнд аврагдах боломж гарч ирнэ. Үүнээс гадна, тэр үед л Сатан шившиглэгдэж, завших ямар ч боломж бололцоогүй, хэрэгжүүлэх ямар ч арга мэхгүй үлдэх болно. Бие махбодтой болсон Бурханы хийдэг ажлыг Бурханы Сүнс биелүүлэх аргагүй, махан биетэй аливаа хүн Бурханы өмнөөс хийж бүр ч чаддаггүй, учир нь Түүний хийдэг ажил хүний амийн төлөө, хүний ялзарсан зан чанарыг өөрчлөхийн төлөө байдаг билээ. Хүн энэ тулаанд оролцсон бол зөвхөн хөөрхийлөлтэйгөөр сандран зугтаж, хүний ялзармал зан чанарыг ер өөрчлөх чадваргүй байх байсан юм. Тэр хүнийг загалмайнаас аварч, бүх тэрслүү хүн төрөлхтнийг байлдан дагуулж чадалгүй, харин зарчмаас хэтэрдэггүй жаахан хуучин ажил эсвэл Сатаныг ялахтай хамаагүй ажил л хийж чадах байсан. Тэгвэл хийж яах юм бэ? Сатаныг ялах нь байтугай хүн төрөлхтнийг ч олж авч чадахгүй ажил ямар ач холбогдолтой юм бэ? Иймээс Сатантай Бурхан Өөрөө л тулалдаж чадах ба хүн үүнийг ердөө хийх чадваргүй юм. Хүний үүрэг бол дуулгавартай байж дагах явдал, учир нь хүн тэнгэр, газрыг бүтээхтэй дүйцэхүйц ажлыг хийх чадваргүй, түүнчлэн Сатантай тулалдах ажлыг ч хийж чадахгүй. Хүн Бурханы Өөрийн удирдлага дор Бүтээгчийн сэтгэлийг хангалуун байлгаж л чадах ба үүний дүнд Сатан ялагддаг; энэ бол хүний хийж чадах цорын ганц зүйл юм. Иймээс шинэ тулаан эхлэх бүрд, өөрөөр хэлбэл, шинэ эрин үеийн ажил эхлэх бүрд энэ ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийж, үүгээр дамжуулан бүхий л эрин үеийг удирдаж, бүх хүн төрөлхтөнд илүү шинэ замыг нээдэг. Шинэ эрин үе бүрийн үүрийн гэгээ нь Сатантай хийх тулааны шинэ эхлэл юм, үүгээр дамжуулан хүн илүү шинэ, илүү үзэсгэлэнтэй ертөнцөд, Бурхан Өөрөө удирддаг шинэ эрин үед ордог. Хүн бол бүх зүйлийн эзэн боловч авхуулсан хүмүүс нь Сатантай хийсэн бүх тулааны үр жимс болох болно. Сатан бол бүх зүйлийг ялзруулагч, бүх тулааны дараах ялагдагч, мөн эдгээр тулааны дараа шийтгэгдэх нэгэн билээ. Бурхан, хүн, Сатан гурвын дундаас Сатан л жигшигдэн, гологдох нэгэн юм. Сатанаар авхуулсан ч Бурханаар буцаан авхуулаагүй хүмүүс нь харин Сатаны өмнөөс шийтгэл хүртэх хүмүүс болох болно. Энэ гурваас Бурханыг л бүх зүйл шүтэн мөргөх ёстой. Харин Сатаны ялзруулсан боловч Бурханы буцаан олж авсан, Бурханы замыг дагадаг хүмүүс нь Бурханы амлалтыг хүлээн авч, Бурханы төлөө муу хүмүүсийг шүүх хүмүүс болдог. Бурхан гарцаагүй ялж, Сатан лавтай ялагдана, харин хүмүүсийн дунд ялах хүмүүс, ялагдах хүмүүс гэж байх болно. Ялдаг хүмүүс нь ялагчдад харьяалагдаж, ялагддаг хүмүүс нь ялагдагчдад харьяалагдана; энэ бол хүн болгоныг төрлийнх нь дагуу ангилж байгаа явдал бөгөөд энэ нь Бурханы бүх ажлын эцсийн үр дүн. Энэ бол Бурханы бүх ажлын зорилго бөгөөд хэзээ ч өөрчлөгдөхгүй. Бурханы удирдлагын төлөвлөгөөний үндсэн ажлын цөм нь хүний аврал дээр төвлөрдөг ба Бурхан үндсэндээ энэ цөмийн төлөө, энэ ажлын төлөө, Сатаныг ялахын тулд махбод болдог. Бурхан анх удаа махбод болсон нь ч Сатаныг ялахын

тулд байсан: Хүн төрөлхтнийг золин аврах ажил болох эхний тулааны ажлыг дуусгахын тулд Тэр биечлэн махбод болж, загалмайд биечлэн цовдлогдсон юм. Үүний адилаар, ажлын энэ үе шатыг ч гэсэн хүмүүсийн дунд ажлаа хийж, үгээ хэлж, Өөрийг нь харах боломжийг хүнд олгохын тулд махбод болсон Бурхан биечлэн хийдэг. Мэдээж Тэр зам зууpаа зарим нэг өөр ажлыг хийх нь гарцаагүй боловч Өөрийн ажлыг биечлэн хийдгийн үндсэн шалтгаан нь Сатаныг ялах, хүн төрөлхтнийг байлдан дагуулах, энэ хүмүүсийг олж авахын төлөө байдаг. Иймээс бие махбодтой болсон Бурханы ажил үнэхээр энгийн хэрэг бус. Хэрвээ Түүний зорилго нь, Бурхан бол даруу, нууцлаг, бодитой гэдгийг хүмүүст харуулах л байсан бол, энэ ажлыг хийхийн төлөө л байсан бол махбод болох хэрэг байхгүй байх байлаа. Бурхан махбод болоогүй ч гэсэн, даруу, нууцлаг, агуу, ариун байдлаа хүнд шууд илчилж чадах байсан, гэхдээ ийм зүйлс нь хүнийг удирдах ажилтай ямар ч хамаагүй. Тэдгээр нь хүнийг аварч, эсвэл бүрэн төгс болгох чадваргүй, Сатаныг ялж бүр ч чадахгүй. Хэрвээ Сатаны ялагдал нь зөвхөн Сүнс сүнснийхээ эсрэг хийх тулаантай л хамааралтай байсан бол, ийм ажлын бодит үнэ цэн бүр ч бага байх байсан; энэ нь хүнийг олж авах чадваргүй байж, хүний хувь заяа, хэтийн ирээдүйг баллах байсан. Иймээс өнөөдрийн Бурханы ажил нь гүн гүнзгий ач холбогдолтой. Энэ нь хүнд зөвхөн Түүнийг харуулж, хүний нүдийг нээж, хүнийг багахан сэтгэл хөдлөл, урам зоригоор хангахын төлөө биш юм; тийм ажил ямар ч ач холбогдолгүй. Хэрвээ чи ийм төрлийн мэдлэгийн талаар л ярьж чаддаг бол бие махбодтой болсон Бурханы жинхэнэ ач холбогдлыг мэддэггүй гэдгийг чинь энэ нь нотолдог.

Бурханы бүхий л удирдлагын төлөвлөгөөний ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийдэг. Эхний үе шат буюу дэлхий ертөнцийн бүтээлийг Бурхан Өөрөө биечлэн хийсэн бөгөөд хэрвээ тэгээгүй бол хэн ч хүн төрөлхтнийг бүтээж чадахгүй байх байлаа; хоёр дахь үе шат нь бүх хүн төрөлхтнийг золин аврах явдал байсан ба үүнийг ч бас Бурхан Өөрөө биечлэн хийсэн; гурав дахь үе шат бол харваас илэрхий юм: Бурханы бүх ажлын төгсгөлийг Бурхан Өөрөө хийх хэрэгцээ бүр ч их бий. Бүх хүн төрөлхтнийг золин аврах, байлдан дагуулах, олж авах, төгс болгох ажлыг бүгдийг нь Бурхан Өөрөө биечлэн хийдэг. Хэрвээ Тэр энэ ажлыг биечлэн хийгээгүй бол Түүний ялгамж чанарыг хүн төлөөлж чадахгүй, ажлыг нь ч хүн хийж чадахгүй байх байв. Сатаныг ялах, хүн төрөлхтнийг олж авах, хүнд газар дээр хэвийн амьдрал өгөхийн тулд Тэр хүмүүсийг биечлэн удирдаж, хүмүүсийн дунд биечлэн ажилладаг; бүхий л удирдлагын төлөвлөгөөнийхөө төлөө, бүх ажлынхаа төлөө энэ ажлыг Тэр биечлэн хийх ёстой. Бурхан өөрт нь үзэгдэж, өөрийг нь баярлуулах гэж ирсэн гэдэгт л хүн итгэвэл тэрхүү итгэлд ямар ч үнэ цэн, ач холбогдол байхгүй. Хүний ойлголт хэтэрхий өнгөц! Бурхан энэ ажлыг Өөрөө хэрэгжүүлснээр л бүрэн дүүрэн, нэгд нэггүй хийж чаддаг. Хүн үүнийг Бурханы өмнөөс хийх чадваргүй. Түүнд Бурханы ялгамж чанар, эсвэл мөн чанар байхгүй учир Түүний ажлыг хийх чадваргүй, хийлээ ч гэсэн ямар ч үр дүнгүй байх байсан. Бурхан эхний удаад махбод болсон нь золин авралын төлөө, бүх хүн төрөлхтнийг нүглээс золин

аврахын төлөө, мөн хүнийг цэвэрлүүлж, нүглээ уучлуулах чадвартай болгохын тулд байсан. Байлдан дагуулах ажлыг ч бас Бурхан хүмүүсийн дунд биечлэн хийдэг. Хэрвээ энэ үе шатанд Бурхан зүгээр л зөгнөл хэлэх байсан бол Түүний оронд эш үзүүлэгч юм уу авьяас билигтэй хүнийг олж болох байв; хэрвээ зөгнөл л хэлэх байсан бол хүн Бурханыг орлож чадна. Харин хүн Бурханы Өөрийн ажлыг биечлэн хийж, хүний амийг боловсруулахаар оролдсон бол энэ ажлыг хийнэ гэдэг хүний хувьд боломжгүй байх байсан юм. Үүнийг Бурхан Өөрөө биечлэн хийх ёстой: Бурхан энэ ажлыг хийхийн тулд Өөрийн биеэр махбод болох ёстой. Үгийн эрин үед хэрвээ зөгнөл л хэлэх байсан бол, эш үзүүлэгч Исаиа ч юм уу Елиа энэ ажлыг хийж чадах байсан, үүнийг Бурхан Өөрөө биечлэн хийх хэрэггүй байх байлаа. Энэ үе шатанд хийдэг ажил нь ердөө л зөгнөл хэлэх явдал биш учраас, мөн хүнийг байлдан дагуулж, Сатаныг ялахад үгийн ажлыг хэрэглэх нь илүү чухал учраас энэхүү ажлыг хүн хийж чадахгүй, Бурхан Өөрөө биечлэн хийх ёстой. Ехова Хуулийн эрин үед Бурханы ажлын нэг хэсгийг хийгээд, дараа нь эш үзүүлэгчдээр дамжуулан зарим нэг үг хэлж, зарим ажлыг хийсэн. Хүн Еховагийн ажлыг орлож чадах байсан учраас, мөн зөнчид Түүний өмнөөс аливаа зүйлийг зөгнөж, зарим нэг зүүдийг тайлж чадах байсан учраас тэр юм. Эхэнд хийсэн ажил нь хүний зан чанарыг шууд өөрчлөх ажил байгаагүй ба хүний нүгэлтэй хамааралгүй байсан, хүн зөвхөн хуулийг мөрдөх шаардлагатай байсан юм. Иймээс Ехова махбод болж, Өөрийгөө хүнд илчлээгүй; үүний оронд Тэр Мосе болон бусад хүнтэй шууд ярьж, Өөрийнхөө өмнөөс тэднийг яриулж, ажиллуулан, хүн төрөлхтний дунд шууд ажиллахад тэднийг хүргэсэн. Бурханы ажлын эхний үе шат нь хүнийг удирдах явдал байлаа. Энэ нь Сатантай хийх тулааны эхлэл байсан боловч энэхүү тулаан хараахан албан ёсоор эхлээгүй байв. Сатантай хийх албан ёсны тулаан нь Бурханыг анх удаа бие махбодтой болоход эхэлж, өнөөдрийг хүртэл үргэлжилсээр ирсэн. Энэхүү дайны эхний тулаан нь бие махбодтой болсон Бурхан загалмайд цовдлогдох үе юм. Бие махбодтой болсон Бурханы цовдлол нь Сатаныг ялсан ба энэ нь дайны эхний амжилттай үе шат байсан. Бие махбодтой болсон Бурхан хүний амийн төлөө шууд ажиллаж эхэлсэн үе нь хүнийг буцаан олж авах ажлын албан ёсны эхлэл байсан бөгөөд энэ нь хүний хуучин зан чанарыг өөрчлөх ажил байсан учраас Сатантай тулаан хийх ажил байлаа. Эхэндээ Еховагийн хийсэн ажлын үе шат нь газар дээрх хүний амьдралыг удирдах төдий байсан. Энэ нь Бурханы ажлын эхлэл байсан бөгөөд ямар ч тулаан, томоохон ажлыг хараахан агуулаагүй боловч айсуй тулааны суурийг тавихын төлөө байсан юм. Дараа нь Нигүүлслийн эрин үе дэх ажлын хоёр дахь үе шат нь хүний хуучин зан чанарыг өөрчлөх явдлыг хамарч байсан, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө хүний амийг боловсруулсан. Бурхан үүнийг биечлэн хийх ёстой байлаа: Бурхан биечлэн махбод болох шаардлагатай болсон. Хэрвээ Тэр махбод болоогүй бол ажлын энэ үе шатанд Түүнийг хэн ч орлож чадахгүй байсан, учир нь энэ нь Сатантай шууд тулалдах ажлыг төлөөлж байсан юм. Хэрвээ хүн энэ ажлыг Бурханы өмнөөс хийсэн бол, Сатаны өмнө зогсох үед нь Сатан бууж өгөхгүй

бөгөөд түүнийг ялна гэдэг боломжгүй байх байв. Бие махбодтой болсон Бурхан л түүнийг ялахаар ирсэн, учир нь бие махбодтой болсон Бурханы мөн чанар нь бурханлаг хэвээр байдаг, Тэр хүний амь, Бүтээгч хэвээрээ байгаа; юу ч болсон бай Түүний ялгамж чанар болон мөн чанар өөрчлөгдөхгүй. Иймээс Сатаныг бүрэн буулгаж авахын тулд Тэр махбод болж, ажил хийсэн. Эцсийн өдрүүдийн ажлын үе шатанд хэрвээ хүн энэ ажлыг хийж, шууд үг хэлэх ёстой байсан бол тэр үг хэлж чадахгүй, зөгнөл хэлсэн бол хүнийг байлдан дагуулж чадахгүй байх байлаа. Бурхан махбод болсноор Сатаныг ялж, бүрэн буулгаж авдаг. Тэрээр Сатаныг бүрмөсөн ялж, хүнийг бүрэн байлдан дагуулж, хүнийг бүрэн олж авахад ажлын энэ үе шат дуусаж, амжилтад хүрнэ. Бурханы удирдлагыг хүн орлож чадахгүй. Ялангуяа эрин үеийг чиглүүлж, шинэ ажлыг эхлүүлэх ажлыг Бурхан Өөрөө биечлэн хийх нь бүр ч хэрэгтэй. Хүнд илчлэл хэлж өгч, зөгнөлөөр хангахыг хүн хийж болно, харин Бурханы биечлэн хийх ёстой ажил буюу Бурхан Сатан хоёрын тулааны ажлыг хүнээр хийлгэж болохгүй. Сатантай хийх тулаан гэж байгаагүй ажлын эхний үе шатанд Ехова эш үзүүлэгчдийн хэлсэн зөгнөлийг ашиглан Израилийн ард түмнийг биечлэн удирдсан. Үүний дараа ажлын хоёр дахь үе шат нь Сатантай хийх тулаан байсан ба Бурхан Өөрөө энэ ажлыг хийхийн тулд биечлэн махбод болж, махбодод ирсэн. Сатантай хийх тулаантай хамаатай аливаа зүйл нь бие махбодтой болсон Бурхантай ч бас хамаатай байдаг нь энэ тулааныг хүнээр хийлгэж болохгүй гэсэн үг юм. Хэрвээ хүн тулалдсан бол Сатаныг ялж чадахгүй байх байв. Хүн Сатаны эзэмшил дор байсаар байж яаж түүний эсрэг тэмцэх хүчтэй байх юм бэ? Хүн дунд нь байдаг: Хэрвээ Сатаныг түшвэл чи Сатанд хамаарна, харин Бурханыг хангалуун байлгавал Бурханд хамаарна. Энэ тулааны ажлыг хүн хийхээр оролдож, Бурханыг орлосон бол чадах байсан уу? Хэрвээ тэгсэн бол хүн аль хэдийн мөхөх байсан биш үү? Аль хэдийн газар дор орчихсон байх биш үү? Иймээс хүн Бурханы ажилд Түүнийг орлох чадваргүй, өөрөөр хэлбэл, хүнд Бурханы мөн чанар байдаггүй бөгөөд хэрвээ чи Сатантай тулалдсан бол ялж чадахгүй байх байсан. Хүн зарим нэг ажлыг л хийж чадна; тэр зарим хүнийг өөртөө татаж чадах боловч Бурханы Өөрийн ажилд Бурханыг орлож чадахгүй. Хүн яаж Сатантай тулалдаж чадах юм бэ? Тулалдаж эхлэхээс чинь өмнө Сатан чамайг олзлон авах байсан. Бурхан Өөрөө Сатантай тулалдаж, тэгээд энэ үндсэн дээр хүн Бурханыг дагаж, Түүнд дуулгавартай байсан цагт л Бурханаар авхуулж, Сатаны хүлээснээс мултарч чадна. Мэргэн ухаан болон чадварааараа хүний хүрч чадах зүйл хэтэрхий хязгаарлагдмал; тэр хүнийг бүрэн төгс болгож, удирдаж, цаашлаад Сатаныг ялж чадахгүй. Хүний оюун билиг, мэргэн ухаан нь Сатаны явуулгыг ялан дийлэх чадваргүй байдаг, иймээс хүн яаж түүнтэй тулалдаж чадах билээ?

Төгс болгуулахыг хүсэж байгаа бүхэнд төгс болгуулах боломж бий, иймээс хүн бүр тайвшрах ёстой: Ирээдүйд та нар бүгд хүрэх газарт орно. Харин чи төгс болгуулах хүсэлгүй, гайхалтай сайхан ертөнцөд орох хүсэлгүй байвал өөрийн чинь л асуудал юм. Төгс болгуулахыг хүсдэг, Бурханд үнэнч, дуулгавартай байж, чиг

үүргээ үнэнчээр биелүүлдэг—ийм бүх хүн төгс болгуулж чадна. Өнөөдөр, үүргээ үнэнчээр биелүүлдэггүй, Бурханд үнэнч биш, Бурханд захирагддаггүй, ялангуяа Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүлээн авсан боловч үүнийгээ хэрэгжүүлдэггүй—ийм бүх хүн төгс болгуулж чадахгүй. Бурханд үнэнч, дуулгавартай байхыг хүсдэг бүх хүн, жаахан мэдлэггүй байсан хэдий ч төгс болгуулж чадна; эрэлхийлэх хүсэлтэй бүх хүн төгс болгуулж чадна. Үүнд санаа зовох хэрэггүй. Чи энэ чиглэлд эрэлхийлэх хүсэлтэй л байвал төгс болгуулж чадна. Би та нараас хэнийг чинь ч хаяж, таягдахыг хүсдэггүй, гэхдээ хэрвээ хүн амжилт гаргахаар хичээхгүй бол өөрийгөө л сүйтгэж байгаа хэрэг; чамайг таягддаг нь Би биш, харин чи өөрөө юм. Чи өөрөө амжилт гаргая гэж хичээдэггүй, залхуурч үүргээ биелүүлдэггүй, үнэнч биш, үнэнийг эрэлхийлдэггүй, үргэлж хүссэнээрээ хийж, дурааараа аашилж, өөрийн алдар хүнд, ашиг хонжооны төлөө тэмцэж, эсрэг хүйстэнтэй харьцахдаа цадиггүй байдаг бол нүглийнхээ ачааг өөрөө үүрэх болно; өөр хэнээр ч өрөвдүүлэх үнэ цэн чамд байхгүй. Миний зорилго бол та бүгдийг төгс болгох, ядаж л байлдан дагуулах явдал, ингэснээр ажлын энэ үе шат амжилттай дуусах боломжтой. Хүн бүрийг төгс болгож, эцэст нь Өөрөө олж авч, бүрэн цэвэрлэж, хайртай хүмүүсээ болгох нь Бурханы хүсэл билээ. Би та нарыг хоцрогдмол гэнэ үү, хэв чанар муутай гэнэ үү хамаагүй, энэ бол бүгд баримт. Миний ингэж хэлдэг нь та нарыг хаях санаатай байгаа, та нарт итгэл алдсан гэдгийг батлахгүй, чамайг аврах хүсэлгүйг минь ч батлахгүй. Өнөөдөр Би та нарыг аврах ажил хийхээр ирсэн, өөрөөр хэлбэл, Миний хийдэг ажил бол авралын ажлын үргэлжлэл юм. Төгс болгуулах боломж хүн бүрд бий: Хүсэж, эрэлхийлж л байгаа тохиолдолд та нар эцэстээ ийм үр дүнд хүрч чадах ба та нараас нэг нь ч хаягдахгүй. Хэрвээ чи дорд хэв чанартай бол, чамд тавих Миний шаардлага дорд хэв чанарт чинь таарсан байх болно; хэрвээ чи дээд хэв чанартай бол чамд тавих Миний шаардлага дээд хэв чанарт чинь таарсан байх болно; хэрвээ чи мэдлэггүй, бичиг үсэгт тайлагдаагүй бол чамд тавих Миний шаардлага бичиг үсэгт тайлагдаагүй байдалд чинь таарсан байх болно; хэрвээ чи бичиг үсэгт тайлагдсан бол чамд тавих Миний шаардлага бичиг үсэгт тайлагдсан гэх баримтын чинь дагуу байх болно; хэрвээ чи ахимаг настай бол чамд тавих Миний шаардлага насанд чинь таарсан байх болно; хэрвээ чи зочломтгой байх чадвартай бол чамд тавих Миний шаардлага үүнд чинь таарсан байх болно; хэрвээ чи зочломтгой байж чадахгүй, харин сайн мэдээг түгээх, чуулганд үйлчлэх, бусад ерөнхий ажил хэрэгт оролцох зэрэг тодорхой чиг үүрэг л биелүүлж чадна гэвэл чамайг төгс болгох маань гүйцэтгэдэг чиг үүрэгт чинь таарсан байх болно. Үнэнч байж, эцсийг нь хүртэл дуулгавартай дагаж, Бурханыг хайрлах дээдийн дээд хайрыг эрэлхийлнэ гэдэг нь чиний биелүүлэх ёстой зүйл бөгөөд энэ гурван зүйлээс илүү сайн хэрэгжүүлэлт гэж үгүй. Эцсийн эцэст хүн энэ гурван зүйлийг биелүүлэх шаардлагатай ба хэрвээ тэдгээрийг биелүүлж чадвал төгс болгуулна. Гэвч юун түрүүнд чи үнэхээр эрэлхийлэх ёстой, урагш, дээш идэвхийлэн зүтгэх ёстой ба тэр тал дээр идэвхгүй

байх ёсгүй. Хүн бүхэн төгс болгуулах боломжтой, мөн төгс болгуулах чадвартай гэж Би хэлсэн, энэ нь үнэн боловч чи эрэл хайгуулдаа сайжрахаар хичээдэггүй. Хэрвээ энэ гурван шалгуурт хүрэхгүй бол чамайг эцэст нь таягдан хаях ёстой. Бүх хүн хөл нийлүүлээсэй, Ариун Сүнсний ажил, гэгээрэлтэй байгаасай, эцсээ хүртэл дуулгавартай байж чаддаг байгаасай гэж Би хүсдэг, учир нь энэ бол та нарын дор бүрнээ биелүүлэх ёстой үүрэг билээ. Та нар бүгд үүргээ биелүүлсэн үедээ төгс болгуулсан байх болно, мөн та нар цангинасан гэрчлэлтэй байх болно. Гэрчлэлтэй бүх хүн нь Сатаныг ялж, Бурханы амлалтыг авсан хүмүүс бөгөөд ирээдүйд гайхалтай хүрэх газарт амьдрахаар үлдэх хүмүүс юм.

БУРХАН ХҮН ХОЁР АМРАЛТАД ХАМТ ОРОХ БОЛНО

Анх Бурхан амарч байсан. Тэр үед газар дэлхий дээр хүмүүс ч, өөр юу ч байгаагүй ба Бурхан ямар ч ажил хийгээгүй байлаа. Хүн төрөлхтөн оршин тогтнож, завхарсан цагаас л Бурхан удирдлагын ажлаа эхэлсэн юм; тэр цагаас хойш Тэр амрахаа болиод, харин оронд нь хүн төрөлхтний дунд завгүй байх болжээ. Хүн төрөлхтний завхралаас болж, мөн тэргүүн тэнгэрэлч тэрсэлснээс болж Бурхан амралтаа алдсан юм. Хэрвээ Бурхан Сатаныг ялж, завхарсан хүн төрөлхтнийг аврахгүй бол дахин хэзээ ч амралтад орж чадахгүй. Хүнд амралт дутагддаг шиг Бурханд ч бас дутагддаг бөгөөд Бурхан дахин нэг удаа амрах үед хүмүүс ч бас амарна. Амралтад амьдарна гэдэг нь дайн дажингүй, бузар буртаггүй, ямарваа шударга бус байдал үлдээгүй амьдрал гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Сатаны үймээн (энд “Сатан” гэдгээр дайсны хүчийг хэлж байна), Сатаны завхралаас ангид, Бурханы эсрэг ямар нэгэн хүчний халдлагад өртдөггүй амьдрал; бүх зүйл өөрсдийн төрлийг дагаж, бүтээлийн Эзэнд шүтэн мөргөдөг, тэнгэр газар тэр аяараа амар амгалан байдаг амьдрал юм—“хүмүүсийн амар тайван амьдрал” гэдгийн утга учир энэ. Бурхан амрах үед газар дээр зөв шударга бус байдал үргэлжлэн оршихоо болино, мөн дайсны хүчний ямар ч халдлага байхаа больж, хүн төрөлхтөн шинэ ертөнцөд орно—тэд Сатаны завхруулсан хүн төрөлхтөн байхаа болиод, харин Сатанаар завхруулагдсаныхаа дараа аврагдсан хүмүүс болно. Хүн төрөлхтний амралтын өдөр ч бас Бурханы амралтын өдөр байх болно. Бурхан анхнаасаа амарч чадаагүйн улмаас биш, харин хүн төрөлхтөн амралтад орох чадваргүйн улмаас Бурхан Өөрийн амралтыг алдсан. Амралтад орно гэдэг нь бүх зүйл хөдлөхөө болих юм уу хөгжихөө болино гэсэн үг биш, Бурхан ажиллахаа больж, хүмүүс амьдрахаа болино гэсэн үг ч биш. Сатан устгагдаж, ёрын муу үйлд нь хамссан хорон санаатнууд шийтгүүлж, газрын хөрснөөс арчигдаж, Бурханд дайсагнагч бүх хүч оршихоо болих үе нь амралтад орохын тэмдэг байх болно. Бурхан амралтад орно гэдэг нь хүн төрөлхтнийг аврах ажлаа хийхээ болино гэсэн үг юм. Хүн төрөлхтөн амралтад орно гэдэг нь бүх хүн Бурханы гэрэл дотор, Түүний

ерөөл дор амьдарна, Сатаны завхрал байхгүй, ямар ч зөв шударга бус зүйл тохиолдохгүй гэсэн үг. Хүмүүс Бурханы халамж дор газар дээр хэвийн амьдарна. Бурхан, хүн хоёр хамтдаа амралтад орох нь хүн төрөлхтөн аврагдаж, Сатан устгагдаж, хүмүүст хийх Бурханы ажил бүхэлдээ дууссан гэсэн утгатай. Бурхан хүмүүс дээр үргэлжлүүлэн ажиллахаа болино, хүмүүс Сатаны эзэмшил дор амьдрахаа болино. Иймээс Бурхан завгүй байхаа больж, хүмүүс ч байнга ийш тийш явахаа болино; Бурхан, хүн хоёр нэгэн зэрэг амралтад орно. Бурхан анхдагч байр сууриндаа буцан очиж, хүн бүр тус тусын байрандаа эргэн очно. Бурханы бүхий л удирдлага дуусмагц Бурхан болон хүмүүсийн оршин суух хүрэх газар энэ юм. Бурханд Бурханы хүрэх газар, хүнд хүний хүрэх газар гэж бий. Амрах зууpаа Бурхан бүх хүний газар дээрх амьдралыг залж чиглүүлсээр байх болно, Бурханы гэрэлд хүмүүс тэнгэр дэх цор ганц жинхэнэ Бурханд шүтэн мөргөнө. Бурхан хүн төрөлхтний дунд амьдрахаа болино, хүмүүс ч Бурхантай хамт Бурханы хүрэх газарт амьдарч чадахгүй болно. Бурхан, хүн хоёр нэг ертөнцөд амьдарч чадахгүй; харин хоёулаа тус тусын амьдрах хэв маягтай байдаг. Бурхан бол бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлдэг Нэгэн, харин бүх хүн төрөлхтөн бол Бурханы удирдлагын ажлын биелэл юм. Удирдуулдаг нь хүмүүс бөгөөд мөн чанар нь Бурханыхтай адилгүй. “Амрах” гэдэг нь анхдагч байрандаа буцан очно гэсэн утгатай. Тиймээс Бурхан амралтад орох үедээ Өөрийн анхдагч байранд буцан очдог гэсэн үг юм. Бурхан газар дээр амьдарч, хүмүүсийн баяр баясал, зовлонг хуваалцахаар дунд нь байхаа болино. Хүмүүс амралтад орох гэдэг нь жинхэнэ бүтээл болсон гэсэн утгатай; тэд газар дээрээс Бурханд шүтэн мөргөж, хэвийн хүний амьдралаар амьдарна гэсэн үг. Хүмүүс Бурханд дуулгаваргүй байж, Бурханыг эсэргүүцэхээ болиод, Адам, Евагийн анхдагч амьдралдаа буцна. Амралтад орсны дараах Бурхан ба хүмүүсийн тус тусын амьдрал, хүрэх газар ийм байх болно. Бурхан, Сатан хоёрын дайнд Сатан ялагдах нь зайлшгүй. Ийм маягаар, Бурхан удирдлагын ажлаа дуусгасны дараа амралтад орох болон хүмүүс бүрэн аврагдаж, амралтад орох нь ч бас зайлшгүй чиг хандлага болсон. Хүний амрах газар дэлхий дээр, Бурханы амрах газар тэнгэрт байдаг. Хүмүүс амралтад Бурханд шүтэн мөргөж, газар дэлхий дээр амьдарна, харин Бурхан үлдсэн хүмүүсийг амралтад залж чиглүүлдэг ба тэднийг газар дэлхийгээс бус, тэнгэрээс залж чиглүүлнэ. Бурхан Сүнс хэвээр байна, харин хүн махан бие хэвээр байна. Бурхан, хүн хоёр хоёулаа өөр өөр амрах хэв маягтай. Бурхан амрах зууpаа хүмүүсийн дунд ирж, харагдана; харин хүмүүс амарч байхдаа Бурханаар удирдуулан тэнгэрт зочилж, тэнгэрийн амьдралыг эдэлнэ. Бурхан, хүн хоёр амралтад орсны дараа Сатан оршин байхаа болино; үүний адилаар хорон муу хүмүүс ч бас оршин байхаа болино. Бурхан, хүн хоёр амралтад орохоос өмнө газар дээр нэгэнтээ Бурханыг хавчиж байсан хорон муу хүмүүс болон газар дээр Түүнд дуулгаваргүй байсан дайснууд аль хэдийн устгагдсан байх болно; тэднийг эцсийн өдрүүдийн агуу гамшиг устгасан байх болно. Тэр хорон муу хүмүүс үндсээрээ устгагдмагц газар дэлхий Сатаны дарлалыг дахин хэзээ ч амсахгүй. Тэр

үед л хүн төрөлхтөн бүрэн аврал хүртэж, Бурханы ажил бүрэн дуусна. Эдгээр нь Бурхан, хүн хоёр амралтад орох урьдчилсан нөхцөл юм.

Бүх зүйлийн төгсгөл ойртоно гэдэг нь Бурханы ажлын төгсгөл, мөн түүнчлэн хүн төрөлхтний хөгжлийн төгсгөлийг илтгэдэг. Энэ нь, Сатаны завхруулсан хүмүүс хөгжлийнхөө эцсийн үе шатанд хүрч, Адам, Евагийн үр удам үржиж дууссан байх болно гэсэн үг юм. Түүнчлэн, Сатаны завхруулсан ийм хүн төрөлхтөн цааш үргэлжлүүлэн хөгжих боломжгүй болно гэсэн утгатай юм. Анх Адам, Ева хоёр завхралд өртөөгүй байсан, харин Еден цэцэрлэгээс хөөгдсөн Адам, Ева хоёр Сатанаар завхруулагдсан байв. Бурхан, хүн хоёр хамтдаа амралтад орох үед Еден цэцэрлэгээс хөөгдсөн Адам, Ева болон тэдний үр хойч эцэст нь төгсгөлдөө очно. Ирээдүйн хүн төрөлхтөн мөн л Адам, Евагийн үр хойчоос бүрдэх боловч Сатаны эзэмшил дор амьдардаг хүмүүс биш байх болно. Харин ч аврагдаж, ариуссан хүмүүс байх болно. Мөн шүүгдэж, гэсгээгдсэн, ариун хүмүүс байх болно. Энэ хүмүүс нь анх байсан хүн төрөлхтөнтэй адилгүй; тэднийг анхны Адам, Ева хоёроос тэс өөр төрлийн хүмүүс гэж хэлэхэд бараг болно. Энэ хүмүүс нь Сатаны завхруулсан бүх хүний дундаас сонгогдсон байх бөгөөд эцэстээ Бурханы шүүлт, гэсгээлтийн үеэр бат зогссон хүмүүс байх болно; тэд завхарсан хүн төрөлхтнөөс үлдсэн сүүлчийн бүлэг хүмүүс байх болно. Энэ хүмүүс л Бурхантай хамт эцсийн амралтад орж чадна. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, гэсгээлтийн ажил буюу ариусгалтын эцсийн ажлын үеэр бат зогсож чаддаг хүмүүс Бурхантай хамт эцсийн амралтад орох хүмүүс байх болно; иймээс амралтад ордог хүмүүс бүгд эцсийн ариусгалтын ажлыг туулсныхаа дараа Сатаны нөлөөнөөс ангижирч, Бурханаар авхуулсан байх болно. Эцэст нь Бурханаар авхуулсан энэ хүмүүс эцсийн амралтад орно. Бурханы гэсгээлт, шүүлтийн ажил нь мөн чанартаа эцсийн амралтынх нь төлөө хүмүүсийг ариусгах зорилготой; тэгж цэвэрлэхгүй бол хүн төрөлхтнөөс нэг нь ч төрлийнхөө дагуу ангилагдаж, амралтад орж чадахгүй. Энэ ажил бол хүн төрөлхтөн амралтад орох цорын ганц зам билээ. Бурханы ариусгалтын ажил л хүмүүсийн зөв шударга бус байдлыг цэвэрлэх ба Түүний гэсгээлт, шүүлтийн ажил л хүн төрөлхтний дуулгаваргүй элементийг ил болгож, улмаар аврагдаж чадах хүмүүсийг чадахгүйгээс нь, үлдэх хүмүүсийг үлдэхгүй хүмүүсээс нь ялгана. Энэ ажил дуусахад үлдэх боломжтой хүмүүс бүгд цэвэрлэгдэж, илүү гайхалтай хоёр дахь амьдралыг эдлэхээр хүн төрөлхтний илүү өндөр байр байдалд орно; өөрөөр хэлбэл, тэд хүний амралтын өдрийг эхлүүлж, Бурхантай зэрэгцэн оршино. Үлдэх боломжгүй хүмүүс гэсгээгдэж, шүүгдсэний дараа жинхэнэ төрх нь бүрмөсөн илчлэгдээд, дараа нь тэд бүгд устгагдаж, Сатаны нэгэн адилаар газар дэлхий дээр амьд үлдэх боломжгүй болно. Ирээдүйн хүн төрөлхтөн дунд ийм төрлийн хүмүүс байхгүй; ийм хүмүүс нь шийтгэлийн бай бөгөөд хорон муу, зөв шударга бус хүмүүс учир эцсийн амралтын газарт ороход тохирохгүй, Бурхан хүн хоёрын хуваалцах амралтын өдөрт ороход ч тэнцэхгүй. Тэд нэгэнтээ золин аврагдсан, бас шүүгдэн гэсгээгдсэн; тэд бас нэгэнтээ Бурханд үйлчлэл үзүүлсэн. Гэвч, сүүлчийн өдөр

ирэхэд хорон муу байдлынхаа улмаас, дуулгаваргүй байдал болон золин аврагдах боломжгүй байдлынхаа улмаас тэд мөн л таягдан хаягдаж, устгагдана; хожмын ертөнцөд тэд хэзээ ч оршин тогтнохгүй, мөн ирээдүйн хүн төрөлхтний дунд цаашид амьдрахгүй. Хүн төрөлхтний дундах ариун хүмүүс амралтад ормогц сүнс ч бай, махан биед амьдарсаар байгаа хүмүүс ч бай хамаагүй, мууг үйлдэгчид болон аврагдаагүй хүмүүс бүгд устгагдана. Мууг үйлдэгч энэ сүнснүүд болон хүмүүс, зөв шударга хүмүүсийн сүнс болон зөв шударгыг үйлдэгч хүмүүсийн тухайд гэвэл, ямар эринд байгаагаас үл хамааран мууг үйлдэгчид эцэстээ бүгд устгагдаж, зөв шударга бүх хүн амьд үлдэнэ. Хүн, эсвэл сүнс аврал хүртэх эсэх нь тэр чигтээ сүүлийн эрин үеийн ажилд үндэслэн шийдэгддэггүй; харин тэд Бурханыг эсэргүүцсэн үү, дуулгаваргүй байсан уу гэдэгт үндэслэн тодорхойлогддог. Өмнөх эринд мууг үйлдээд, аврал хүртэж чадаагүй хүмүүс эргэлзээгүй шийтгэлийн бай болох бөгөөд одоогийн эринд мууг үйлддэг, аврагдаж чадахгүй хүмүүс ч бас шийтгэлийн бай болох нь гарцаагүй. Хүмүүсийг амьдардаг эринийх нь дагуу биш, харин сайн муугийн үндсэн дээр ангилдаг. Ийнхүү ангилмагцаа тэднийг тэр даруй шийтгэж, шагнадаггүй; харин Бурхан эцсийн өдрүүд дэх байлдан дагуулалтын ажлаа хийж дууссаныхаа дараа л мууг шийтгэх, сайныг шагнах ажлаа гүйцэтгэнэ. Үнэндээ Тэрээр хүн төрөлхтнийг аврах ажлаа хийж эхэлснээсээ хойш хүмүүсийг сайн муугаар нь ангилсаар ирсэн. Гэхдээ Өөрийнх нь ажил дууссаны дараа л Тэрээр зөв шударга хүмүүсийг шагнаж, хорон мууг шийтгэнэ; ажлаа дуусгаад Тэр тэднийг ангилж, дараа нь мууг шийтгэж, сайныг шагнах ажлаа нэн даруй эхэлдэг юм биш. Харин ч Өөрийнх нь ажил бүрэн дуусах үед л үүнийг хийнэ. Мууг шийтгэж, сайныг шагнах Бурханы эцсийн ажлын ар дахь бүхий л зорилго нь бүх хүнийг бүрмөсөн ариусгах явдал юм, ингэснээр Тэр цэвэр ариун хүн төрөлхтнийг мөнхийн амралтад аваачна. Түүний ажлын энэ үе шат хамгийн чухал; энэ нь Түүний бүхий л удирдлагын ажлын сүүлчийн үе шат билээ. Хэрвээ Бурхан хорон мууг устгалгүй үлдээсэн бол бүх хүн амралтад орж чадахгүй хэвээр байх байсан бөгөөд Бурхан бүх хүн төрөлхтнийг илүү сайхан ертөнцөд аваачиж чадахгүй байх байлаа. Ийм ажил нь бүрэн гүйцэд биш юм. Бурханы ажил дуусах үед бүх хүн төрөлхтөн бүхэлдээ ариун болно; ийм маягаар л Бурхан амралтад санаа амар амьдарч чадна.

Өнөө үед хүмүүс махан биеийн зүйлсээс салж чадахгүй хэвээр байна; тэд махан биеийн таашаал, дэлхий ертөнц, мөнгө хөрөнгө, завхарсан зан чанараа орхиж чаддаггүй. Ихэнх хүмүүс эрэл хайгуулаа хааш яаш байдлаар явуулдаг. Үнэндээ энэ хүмүүсийн зүрх сэтгэлд Бурхан огт байдаггүй; тэр ч бүү хэл тэд Бурханаас айдаггүй. Зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй учир тэд Бурханы хийдэг бүхнийг ойлгож чаддаггүй ба Түүний айлддаг үгэнд итгэж бүр ч чаддаггүй. Ийм хүмүүс хэтэрхий махан биеийнх; хэтэрхий гүн завхарсан, ямар ч үнэнгүй байдаг. Тэр ч бүү хэл, Бурхан махбод болж чадна гэдэгт итгэдэггүй. Бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй—өөрөөр хэлбэл, нүдэнд үзэгддэг Бурханд юм уу Түүний үг, ажилд итгэдэггүй, харин тэнгэр дэх үл үзэгдэх Бурханд шүтэн мөргөдөг хэн боловч

зүрх сэтгэлдээ Бурхангүй хүн юм. Ийм хүмүүс тэрслүү агаад Бурханыг эсэргүүцдэг. Тэдэнд хүн чанар, эрүүл ухаан дутагддаг, үнэний тухайд бол ярихын ч хэрэггүй. Түүнчлэн, энэ хүмүүсийн хувьд, нүдэнд үзэгдэж, гарт баригддаг Бурханд тэр тусмаа итгэж болохгүй мөртөө үл үзэгдэх, биет бус Бурханыг хамгийн үнэмшилтэй, хамгийн бахдалтай гэж үздэг. Тэдний эрж хайдаг зүйл нь бодит үнэн биш, амьдралын жинхэнэ мөн чанар ч биш; Бурханы хүсэл бүр ч биш юм. Харин ч тэд сэтгэл хөөрлийг эрэлхийлдэг. Тэдний хүслийг хамгийн сайн биелүүлж чадах зүйлс нь эргэлзээгүй тэдний итгэдэг, тэдний эрэлхийлдэг зүйл юм. Тэд үнэнийг эрж хайхын төлөө биш, өөрсдийнхөө хүслийг хангахын төлөө л Бурханд итгэдэг. Ийм хүмүүс мууг үйлдэгчид биш гэж үү? Тэд өөрсдөдөө туйлын итгэлтэй байдаг бөгөөд өөрсөд шиг нь ийм “сайн хүмүүсийг” тэнгэр дэх Бурхан устгана гэдэгт огтхон ч итгэдэггүй. Харин ч тэд Бурханы төлөө олон зүйл хийж, Түүнд ихээхэн “үнэнч” гэдгээ харуулсан учир Бурхан өөрсдийг нь үлдээгээд зогсохгүй, өгөөмрөөр шагнана гэдэгт итгэдэг. Хэрвээ тэд бас нүдэнд үзэгдэх Бурханыг эрэлхийлсэн бол өөрсдийнх нь хүсэл биелэхээ больмогц тэр дор нь Бурханы эсрэг хариу довтолж, уур хилэнд автах байлаа. Тэд өөрсдийнхөө хүслийг л хангахаар эрэлхийлдэг булай хүмүүс гэдгээ харуулдаг; тэд үнэнийг эрэлхийлж буй ёс жудагтай хүмүүс биш. Ийм хүмүүс бол Христийг дагадаг хорон санаатнууд гээч юм. Үнэнийг эрж хайдаггүй тэр хүмүүс үнэнд итгэж чаддаггүй ба хүн төрөлхтний ирээдүйн төгсгөлийг ухамсарлаж бүр ч чаддаггүй, учир нь тэд нүдэнд үзэгддэг Бурханы ямар ч үг, ажилд итгэдэггүй—хүмүүсийн хожмын хүрэх газарт итгэж чаддаггүй байх ч үүнд багтана. Тиймээс тэд нүдэнд үзэгдэх Бурханыг дагаж байсан ч гэсэн ёрын мууг үйлдсээр байдаг бөгөөд үнэнийг огт эрж хайдаггүй, Миний шаарддаг үнэнийг ч хэрэгжүүлдэггүй. Устгагдана гэдэгтээ итгэдэггүй энэ хүмүүс харин ч эсрэгээрээ яг устгагдах хүмүүс юм. Тэд маш ухаалаг гэдэгтээ итгэдэг бөгөөд өөрсдийгөө үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс гэж боддог. Тэд ёрын муу үйлдлээ үнэн гэж үздэг, тиймээс үүнийгээ нандигнадаг. Ийм хорон муу хүмүүс өөрсдөдөө маш итгэлтэй байдаг; тэд үнэнийг хоосон сургаал гэж үзэн, ёрын муу үйлдлүүдээ үнэн гэж үздэг ч эцэстээ юу тарина, түүнийгээ л хураана. Хүмүүс өөртөө илүү итгэлтэй, асар биеэ тоосон байх тусмаа үнэнийг олж авч чаддаггүй; тэнгэр дэх Бурханд итгэх тусмаа Бурханыг улам их эсэргүүцдэг. Энэ хүмүүс бол шийтгэгдэх хүмүүс юм. Хүн төрөлхтөн амралтад орохоос өмнө төрөл бүрийн хүн шийтгэгдэх үү, шагнагдах уу гэдэг нь үнэнийг эрж хайсан эсэх, Бурханыг мэддэг эсэх, нүдэнд үзэгддэг Бурханд дуулгавартай байж чаддаг эсэхээр тодорхойлогдоно. Нүдэнд үзэгддэг Бурханд үйлчлэл үзүүлсэн боловч Түүнийг мэддэггүй, дуулгавартай дагадаггүй хүмүүст үнэн байдаггүй. Энэ хүмүүс бол мууг үйлдэгчид бөгөөд мууг үйлдэгчид гарцаагүй шийтгэлийн бай болно; түүнчлэн тэд хорон муу үйлдлийнхээ дагуу шийтгүүлнэ. Хүмүүс Бурханд итгэж, бас Түүнд дуулгавартай байвал зохино. Тодорхойгүй, үл үзэгдэх Бурханд л итгэдэг хүмүүс бол Бурханд итгэдэггүй, Бурханд захирагдаж чаддаггүй хүмүүс юм. Хэрвээ энэ хүмүүс, Бурханы байлдан дагуулалтын ажил дуусах үед нүдэнд үзэгддэг Бурханд

мөн л итгэж чадахгүй, махбодоор үзэгддэг Бурханд дуулгаваргүй байж, эсэргүүцсээр байх юм бол энэ “тодорхойгүй үзэлтнүүд” эргэлзээгүй сүйрлийн бай болно. Та нарын дунд буй хүмүүсийн хувьд ч адилхан—бие махбодтой болсон Бурханыг үгээрээ хүлээн зөвшөөрдөг ч бие махбодтой болсон Бурханд дуулгавартай байх үнэнийг хэрэгжүүлж чаддаггүй хэн боловч эцэстээ таягдан хаягдаж, устгагдана. Түүнчлэн, нүдэнд үзэгддэг Бурханыг үгээрээ хүлээн зөвшөөрч, Түүний илэрхийлсэн үнэнийг идэж, уудаг мөртөө тодорхойгүй, үл үзэгдэх Бурханыг ч бас эрж хайдаг хүмүүс гарцаагүй мөхлийн бай болно. Энэ хүмүүсийн аль нь ч Бурханы ажил дууссаны дараа амралтын цаг үе ирэх хүртэл үлдэж чадахгүй, мөн амралтын цаг үед ийм хүмүүстэй адил төстэй ганц ч хүн үлдэж чадахгүй. Чөтгөрлөг хүмүүс бол үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс юм; Бурханыг эсэргүүцэж, дуулгаваргүй байх нь тэдний мөн чанар бөгөөд Бурханд захирагдах санаа зорилго тэдэнд өчүүхэн төдий ч байдаггүй. Ийм хүмүүс бүгд устгагдана. Чамд үнэн байгаа эсэх, чи Бурханыг эсэргүүцдэг эсэх нь чиний харагдах байдал, хааяа яаж ярьж, яаж биеэ авч явдгаас биш, харин мөн чанараас чинь хамаардаг. Хүн устгагдах уу, үгүй юу гэдэг нь мөн чанараар нь тодорхойлогддог; энэ нь хүний зан авир, үнэний эрэл хайгуулаар илчлэгддэг мөн чанарынх нь дагуу тодорхойлогддог. Ажлыг нэг нэгэнтэйгээ ижилхэн хийдэг, ижил хэмжээний ажил хийдэг хүмүүсийн дундаас мөн чанар нь сайн, үнэнийг эзэмшдэг хүмүүс үлдэнэ, харин мөн чанар нь ёрын муу агаад нүдэнд үзэгдэх Бурханыг дуулгавартай дагадаггүй хүмүүс сүйрлийн бай болно. Хүн төрөлхтний хүрэх газартай хамаатай Бурханы бүх ажил юм уу үг нь хүн бүрийн мөн чанарын дагуу, хүмүүстэй зүй зохистойгоор харьцана; өчүүхэн ч эндүүрэл тохиолдохгүй, мөн ганц ч алдаа мадаг гарахгүй. Хүмүүс ажил хийх үед л хүний сэтгэл хөдлөл, санаа зорилго үүнд холилддог. Бурханы хийдэг ажил хамгийн зохистой; Тэрээр аливаа бүтээлийг огтхон ч хилсээр буруутгадаггүй. Хүн төрөлхтний ирээдүйн хүрэх газрыг ухамсарлаж чаддаггүй, Миний айлддаг үгэнд итгэдэггүй хүмүүс одоо олон бий. Итгэдэггүй, мөн үнэнийг хэрэгжүүлдэггүй хүмүүс бүгд чөтгөрүүд юм!

Одоо, эрж хайдаг ба эрж хайдаггүй хүмүүс нь хоёр өөр төрлийн хүмүүс бөгөөд хүрэх газар нь ч бас маш өөр байдаг. Үнэний мэдлэгийг эрэлхийлж, үнэнийг хэрэгжүүлэгчид бол Бурханы аврах хүмүүс юм. Үнэн замыг мэддэггүй хүмүүс бол чөтгөрүүд, дайснууд; тэд бол тэргүүн тэнгэрэлчийн үр удам бөгөөд сүйрлийн бай болох болно. Тодорхойгүй Бурханд сүсэглэн итгэгчид ч гэсэн чөтгөрүүд биш үү? Мөс чанар сайтай ч үнэн замыг хүлээн авдаггүй хүмүүс бол чөтгөрүүд юм; Бурханыг эсэргүүцэх нь тэдний мөн чанар. Үнэн замыг хүлээн авдаггүй хүмүүс бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс бөгөөд ийм хүмүүс олон зовлон бэрхшээл туулласа ч гэсэн мөн л устгагдана. Дэлхий ертөнцийг орхих хүсэлгүй, эцэг эхээсээ салж тэвчдэггүй, махан биеийн зугаа цэнгэлээсээ ангижирч чаддаггүй хүмүүс бүгд Бурханд тэрслүү байдаг бөгөөд бүгдээрээ сүйрлийн бай болно. Бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй хэн боловч чөтгөрийнх байдгаас гадна тэд устгагдах болно. Итгэдэг

боловч үнэнийг хэрэгжүүлдэггүй, бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй, Бурханы оршин тогтнолд огт итгэдэггүй хүмүүс ч бас сүйрлийн бай болно. Үлдэх хүмүүс бол цэвэршүүлэлтийн зовлонг туулж, бат зогссон хүмүүс юм; тэд бол шалгалтыг үнэхээр даван туулсан хүмүүс билээ. Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй хэн боловч дайсан; өөрөөр хэлбэл, бие махбодтой болсон Бурханыг хүлээн зөвшөөрдөггүй хэн боловч—энэ урсгалын гадна ч бай, дотор ч бай хамаагүй—антихрист юм! Сатан гэж хэн бэ, чөтгөрүүд гэж хэн бэ, Бурханы дайснууд гэж хэн бэ, Бурханд итгэдэггүй эсэргүүцэгчид биз дээ? Тэд Бурханд дуулгаваргүй хүмүүс биш гэж үү? Тэд амаараа л Бурханд итгэдэг гэдэг ч үнэнгүй хүмүүс биш гэж үү? Тэд Бурханд гэрчлэл хийж чадахгүй атлаа ерөөл олж авахаар л эрэлхийлдэг хүмүүс биш гэж үү? Чи өнөөдөр тэр чөтгөрүүдтэй холилдож, тэдэнд мөс чанар, хайраар хандсаар байгаа, гэхдээ энэ тохиолдолд чи Сатанд сайхан сэтгэл гаргаж байгаа бус уу? Чөтгөрүүдтэй сүлбэлдсэн бус уу? Хүмүүс өнөө үед сайн, мууг ялган салгаж чадахгүй хэвээр, Бурханы хүслийг эрж хайх ямар ч санаа зорилгогүйгээр сохроор хайрлаж, өршөөсөөр байж, Бурханы санаа зорилгыг өөрсдийн болгож чадахгүй бол тэдний төгсгөл бүр ч золгүй байх болно. Махбод дахь Бурханд итгэдэггүй хэн боловч Бурханы дайсан юм. Дайсанд хайр, мөс чанар харуулж чаддаг бол чи зөв шударга байдлын мэдрэмжгүй байгаа бус уу? Миний жигшиж, санал зөрөлддөг хүмүүстэй нийцтэй байж, тэднийг гэх хайр, хувийн сэтгэл хөдлөлөө харуулсаар байгаа бол чи тэрслүү байгаа бус уу? Чи Бурханыг зориуд эсэргүүцэж байгаа бус уу? Ийм хүнд үнэн байдаг гэж үү? Хүмүүс дайснууддаа мөс чанар гаргаж, чөтгөрүүдийг хайрлаж, Сатаныг өршөөдөг бол Бурханы ажилд санаатайгаар саад хийж байгаа хэрэг бус уу? Зөвхөн Есүст л итгээд, эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурханд итгэдэггүй хүмүүс, түүнчлэн бие махбодтой болсон Бурханд итгэдэг гэж амаараа хэлдэг ч мууг үйлддэг хүмүүс бүгд антихристүүд, Бурханд ч итгэдэггүй хүмүүсийг бүр дурдахын ч хэрэггүй. Энэ хүмүүс бүгд сүйрлийн бай болно. Бусдыгаа үнэлж шүүдэг хүмүүсийн стандарт зан авирт нь үндэслэдэг; үйлдэл нь сайн бол зөв шударга хүн, харин үйлдэл нь жигшүүртэй бол хорон муу хүн байдаг. Хүмүүсийг үнэлж шүүдэг Бурханы стандарт бол тэдний мөн чанар Өөрт нь дуулгавартай байгаа эсэхэд үндэслэдэг; уг хүний зан авир сайн, муу эсэх, үг яриа нь зөв буруу эсэхээс үл хамааран Бурханд дуулгавартай хүн бол зөв шударга хүн, харин дуулгаваргүй хүн бол дайсан, хорон муу хүн юм. Зарим хүн ирээдүйд сайхан хүрэх газар олж авахын тулд сайн үйл ашиглахыг хүсдэг, зарим хүн сайн хүрэх газартай болохын тулд сайхан үг яриа ашиглахыг хүсдэг. Бурхан зан авирыг нь харж, үг яриаг нь сонссоныхоо дараа хүмүүсийн төгсгөлийг тодорхойлдог гэж хүн бүр эндүүрэн боддог; тиймээс олон хүн үүнийг далимдуулан Бурханыг мэхэлж түр зуурын ивээл олж авахыг хүсдэг. Ирээдүйд, амралтын байдалд амьд үлдэх хүмүүс бүгд гай зовлонгийн өдрийг туулж, бас Бурханд гэрчлэл хийсэн байх болно; тэд бүгд үүргээ биелүүлсэн, Бурханд зориуд захирагдсан хүмүүс байх болно. Үнэнийг хэрэгжүүлэхээс зайлсхийх зорилгоор үйлчлэл үзүүлэх боломжийг

ашиглахыг хүсдэг хүмүүс үлдэж чадахгүй. Хүн нэг бүрийн төгсгөлийг зохицуулах зүй зохистой стандарт Бурханд бий; Тэрээр хүний үг, үйлдэлд үндэслэн эдгээр шийдвэрийг гаргадаггүй, бас нэгэн үед гаргасан зан авирынх нь дагуу ч шийддэггүй. Урьд нь Өөрт нь үйлчилснээс болоод Бурхан хүний хорон муу үйлдэлд яавч өршөөнгүй хандахгүй, мөн Бурханы төлөө цагаа зарлагадсанаас нь болоод хүнийг үхлээс хэлтрүүлэхгүй. Хорон муу байдлынхаа төлөө цээрлэл хүлээхээс хэн ч зайлж чадахгүй ба хэн ч ёрын муу үйлдлээ нууж, улмаар сүйрлийн тарчлаанаас зугтаж чадахгүй. Хэрвээ хүмүүс өөрсдийнхөө үүргийг үнэхээр биелүүлж чаддаг бол, ерөөл хүртэх, золгүй явдал туулахаас үл хамааран Бурханд мөнхөд үнэнч байж, шагналын араас хөөцөлддөггүй гэсэн үг юм. Хүмүүс ерөөл харах үедээ Бурханд үнэнч байдаг ч ямар нэгэн ерөөл харж чадахгүй үедээ үнэнч байдлаа алдаж, эцэстээ Бурханд гэрчлэл хийж мөн л чаддаггүй, оногдсон үүргээ биелүүлж чаддаггүй бол Бурханд урьд нь нэгэнтээ үнэнчээр үйлчлэл үзүүлсэн байлаа ч гэсэн тэд сүйрлийн бай хэвээр байна. Товчхондоо бол хорон муу хүмүүс мөнхөд амьд үлдэж чадахгүй, амралтад ч орж чадахгүй; зөв шударга хүмүүс л амралтын эзэд юм. Хүн төрөлхтөн зөв замд ормогц хүмүүс хэвийн хүний амьдралтай болно. Тэд бүгд тус тусын үүргээ биелүүлж, Бурханд туйлын үнэнч байна. Тэд тэрслүү байдал болон завхарсан зан чанараа бүрмөсөн хаяад, Бурханы төлөө, Бурханаас үүдэн амьдарна, дуулгаваргүй байдал, эсэргүүцлийн аль нь ч байхгүй байна. Бас тэд бүгд Бурханд бүрэн дуулгавартай байж чадна. Энэ нь Бурхан, хүн хоёрын амьдрал; хаанчлалын амьдрал, амралтын амьдрал байх болно.

Огтоос үл итгэгч үр хүүхэд, хамаатан саднаа чуулган руу чирдэг хүмүүс бүгд туйлын аминчхан бөгөөд зүгээр л сайхан сэтгэл гаргаж байгаа. Нөгөөдүүл нь итгэдэг эсэхийг үл хайхран, энэ нь Бурханы хүсэл мөн эсэхээс үл хамааран энэ хүмүүс хайр энэрэлтэй байхад л анхаардаг. Зарим хүн Бурханы өмнө эхнэрээ авчирдаг, эсвэл эцэг эхээ Бурханы өмнө авчирдаг бөгөөд Ариун Сүнс үүнийг зөвшөөрөх эсэх, тэдэн дээр ажиллаж буй эсэхээс үл хамааран Бурханы төлөө “авьяастай хүмүүсийг” сохроор сонгон авсаар байдаг. Энэ үл итгэгчдэд сайхан сэтгэл гаргах нь ямар ашиг тустай байж болох вэ? Ариун Сүнсний дэргэд байдаггүй энэ үл итгэгчид Бурханыг дагахаар чармайсан ч хүмүүсийн төсөөлдөг шиг аврал хүртэж мөн л чадахгүй. Аврал хүлээн авч чадах хүмүүсийг олж авах нь үнэндээ тийм ч амархан биш. Ариун Сүнсний ажил болон шалгалтыг туулаагүй, бие махбодтой болсон Бурханаар төгс болгуулаагүй хүмүүс бүрэн төгс болгуулж огтхон ч чадахгүй. Тиймээс, Бурханыг нэр төдий дагаж эхлэх мөчөөсөө эхлээд энэ хүмүүс Ариун Сүнсний дэргэд байдаггүй. Нөхцөл байдал, бодит байр байдлаасаа шалтгаалан тэд бүрэн төгс болгуулж ер чадахгүй. Иймээс Ариун Сүнс тэдэнд их эрч хүч зарцуулахаар шийддэггүй, мөн тэднийг аливаа гэгээрлээр хангаж, ямар нэгэн байдлаар залж чиглүүлдэггүй; Тэр тэдэнд зүгээр л дагах боломж олгож, эцэст нь тэдний төгсгөлийг илчилнэ—энэ л хангалттай. Хүний урам зориг, санаа зорилго Сатанаас гардаг бөгөөд эдгээр зүйл Ариун Сүнсний ажлыг гүйцэлдүүлж яавч

чадахгүй. Хүмүүс ямархуу байх нь хамаагүй Ариун Сүнсний ажилтай байх ёстой. Хүмүүс бусад хүнийг бүрэн төгс болгож чадах уу? Нөхөр нь яагаад эхнэрээ хайрладаг вэ? Мөн эхнэр нь яагаад нөхрөө хайрладаг вэ? Хүүхдүүд нь яагаад эцэг эхдээ ачлалтай байдаг вэ? Эцэг эхчүүд яагаад үр хүүхдүүдээ ухаангүй хайрладаг вэ? Хүмүүс үнэндээ ямар санаа зорилго өвөрлөдөг вэ? Тэд өөрсдийн төлөвлөгөө, аминч хүслийг хангах зорилготой байдаг бус уу? Тэд үнэхээр Бурханы удирдлагын төлөвлөгөөний төлөө ажиллах гэдэг үү? Тэд үнэхээр Бурханы ажлын төлөө ажиллаж байгаа юу? Бүтээгдсэн зүйлийн үүргийг биелүүлэх зорилготой байдаг уу? Бурханд итгэж эхэлсэн мөчөөсөө л Ариун Сүнсний өмнө байж чадаагүй хүмүүс Ариун Сүнсний ажлыг хэзээ ч олж авч чадахгүй; энэ хүмүүс харваас устгагдах бай юм. Хүн тэднийг хэчнээн их хайрлах нь хамаагүй, Ариун Сүнсний ажлыг орлож чадахгүй. Хүмүүсийн урам зориг, хайр нь хүний санаа зорилгыг төлөөлдөг боловч Бурханы санаа зорилгыг төлөөлж чадахгүй, Бурханы ажлыг орлож ч чадахгүй. Бурханд нэр төдий итгэж, Түүнийг дагадаг дүр эсгэдэг боловч Бурханд итгэнэ гэж юу болохыг мэддэггүй хүмүүст байж болох хамгийн их хайр, өрөвдөх сэтгэлийг үзүүлсэн ч гэсэн тэд Бурханы энэрлийг олж авахгүй, Ариун Сүнсний ажлыг ч олж авахгүй. Бурханыг чин сэтгэлээсээ дагадаг хүмүүс хэв чанар муутай байж, олон үнэнийг ойлгож чаддаггүй байсан ч гэсэн Ариун Сүнсний ажлыг хаяа олж авч бас л чадна; харин нэлээд сайн хэв чанартай хэр нь чин сэтгэлээсээ итгэдэггүй хүмүүс Ариун Сүнсний өмнө байж ер чадахгүй. Ийм хүмүүсийг аврах боломж огт байхгүй. Тэд Бурханы үгийг уншиж, хаяа номлол сонсож, эсвэл Бурханыг магтан дуулж байсан ч гэсэн эцэстээ амралтын үе хүртэл амьд үлдэж чадахгүй. Хүмүүс чин сэтгэлээсээ эрж хайдаг эсэх нь бусад хүмүүс тэднийг хэрхэн үнэлж шүүдгээр, эргэн тойрных нь хүмүүс тэднийг хэрхэн үздэгээр бус, харин Ариун Сүнс тэдэн дээр ажилладаг эсэх, дэргэд нь Ариун Сүнс байдаг эсэхээр тодорхойлогддог. Түүнчлэн, тодорхой хугацаанд Ариун Сүнсний ажлыг туулсны дараа зан чанар нь өөрчлөгдсөн эсэх, Бурханы талаар мэдлэгтэй болсон эсэхээс хамаардаг. Хэрвээ Ариун Сүнс хүн дээр ажиллавал энэ хүний зан чанар аажмаар өөрчлөгдөж, Бурханд итгэх талаарх үзэл бодол нь аажмаар цэвэр ариун болно. Хүмүүс Бурханыг хэр удаан дагасан нь хамаагүй, тэд өөрчлөгдсөн л бол Ариун Сүнс тэдэн дээр ажиллаж байгаа гэсэн үг юм. Хэрвээ тэд өөрчлөгдөөгүй бол Ариун Сүнс тэдэн дээр ажиллаагүй гэсэн утгатай. Энэ хүмүүс зарим нэг үйлчлэл үзүүлдэг ч бай, ерөөл хүртэх хүсэл нь тэднийг өдөөдөг. Хаяахан л үйлчлэл үзүүлэх нь зан чанартаа өөрчлөлт гаргасныг орлож чадахгүй. Эцэстээ тэд мөн л устгагдана, учир нь хаанчлалд үйлчлэл үзүүлэгчид хэрэггүй, мөн төгс болгуулсан, Бурханд үнэнч хүмүүст зан чанар нь өөрчлөгдөөгүй хэн ч үйлчлэх хэрэггүй байх болно. Урьд нь хэлсэн “Хүн Эзэнд итгэх үед бүхий л гэр бүлд нь ерөөгддөг” гэх үг Нигүүлслийн эрин үед тохиромжтой боловч хүн төрөлхтний хүрэх газартай холбоогүй. Энэ нь Нигүүлслийн эрин үеийн нэг үе шатанд л зохимжтой. Энэ үгийн утга нь хүмүүсийн эдэлдэг амар амгалан болон материаллаг ерөөлд чиглэсэн; энэ нь Эзэнд итгэдэг

хүний бүх гэр бүл аврагдана гэсэн үг биш, мөн нэг хүн ерөөл хүртэх үед бүх гэр бүлийнхэн нь бас амралтад хүргэгдэж чадна гэсэн утгатай ч биш юм. Хүн ерөөл хүртэх, зовлон амсах эсэх нь тухайн хүний мөн чанарын дагуу тодорхойлогддог болохоос бусдынхтай адил нийтлэг мөн чанарынх нь дагуу тодорхойлогддоггүй. Хаанчлалд иймэрхүү хэллэг, эсвэл дүрэм журам огт байдаггүй. Хүн эцэстээ амьд үлдэж чадвал Бурханы шаардлагыг хангаснаас болж байгаа бөгөөд эцэстээ амралтын үе хүртэл үлдэж чадахгүй бол Бурханд тэрсэлж, Бурханы шаардлагыг биелүүлээгүйгээс болж байгаа юм. Хүн бүрд тохирох хүрэх газар гэж бий. Эдгээр хүрэх газар нь хувь хүн бүрийн мөн чанарын дагуу тодорхойлогддог бөгөөд бусад хүмүүстэй ямар ч хамаагүй. Хүүхдийн хорон муу үйлдлийг эцэг эхэд нь тохож болохгүй, зөв шударгыг нь ч эцэг эхтэй нь хуваалцаж болохгүй. Эцэг эхийнх нь хорон муу үйлдлийг үр хүүхдэд нь тохож болохгүй, мөн эцэг эхийнх нь зөв шударгыг үр хүүхдүүдтэй нь хуваалцаж болохгүй. Хүн бүр өөрсдийн нүглийг үүрч, хүн бүр тус тусын ерөөлийг эдэлдэг. Хэн ч өөр хүнийг орлож чадахгүй; энэ нь зөв шударга байдал юм. Хүний өнцгөөс бол хэрвээ эцэг эх нь ерөөл хүртвэл үр хүүхдүүд нь ч бас хүртэж чадах бөгөөд үр хүүхдүүд нь мууг үйлдвэл эцэг эх нь тэдний нүглийг нөхөн төлөх ёстой байдаг. Энэ бол хүний үзэл бодол, аливааг хийх хүний арга зам юм; энэ нь Бурханы үзэл бодол биш. Хүн бүрийн төгсгөл, үйлдлээс нь гардаг мөн чанарынх нь дагуу тодорхойлогддог ба энэ нь үргэлж зүй зохистойгоор тодорхойлогддог. Хэн ч өрөөл бусдын нүглийг үүрч чадахгүй; тэр тусмаа хэн ч өөр хүний оронд шийтгэл хүлээж чадахгүй. Энэ нь маргаангүй. Үр хүүхдээ гэх эцэг эхийн хайр халамж байлаа гээд үр хүүхдийнхээ оронд зөв шударга үйл хийж чадна гэсэн үг биш, мөн эцэг эхээ гэсэн үр хүүхдийн ачлалт хайр байлаа гээд эцэг эхийнхээ оронд зөв шударга үйл хийж чадна гэсэн үг биш. “Тэр үед хоёр хүн талбайд байна; нэгийг нь авч, нөгөөг нь үлдээнэ. Хоёр эмэгтэй тээрэм дээр тээрэмдэж байна; нэгийг нь авч, нөгөөг нь орхино” гэх үгийн жинхэнэ утга учир энэ юм. Үр хүүхдээ гэх их хайрандаа үндэслэн мууг үйлдэгч хүүхдүүдээ амралтад аваачиж хэн ч чадахгүй, мөн өөрийн зөв шударга үйлдлийн үндсэн дээр эхнэрээ (эсвэл нөхрөө) амралтад аваачиж хэн ч чадахгүй. Энэ бол захиргааны дүрэм; хэн ч үүнээс ангид байж чадахгүй. Эцсийн эцэст, зөв шударгыг үйлдэгчид нь зөв шударгыг үйлдэгчид, мууг үйлдэгчид нь мууг үйлдэгчид юм. Зөв шударга хүмүүс эцэстээ амьд үлдэнэ, харин мууг үйлдэгчид устгагдана. Ариун хүмүүс бол ариун; тэд бузар биш. Бузар хүмүүс бол бузар, тэдэнд ганц ч ариун хэсэг байдаггүй. Хорон муу хүмүүсийн үр хүүхдүүд зөв шударга үйл хийлээ ч гэсэн, зөв шударга хүний эцэг эх ёрын муу үйл хийлээ ч гэсэн, бүх хорон муу хүн устгагдаж, бүх зөв шударга хүн амьд үлдэнэ. Итгэдэг нөхөр, итгэдэггүй эхнэрийн хооронд ямар ч холбоо байхгүй ба итгэдэг үр хүүхэд, итгэдэггүй эцэг эх хоорондоо ямар ч холбоогүй байдаг; тэд бол огт таарахгүй хоёр төрлийн хүмүүс юм. Амралтад орохоос өмнө хүнд махан биеийн хамаатан садан байдаг ч амралтад ормогц яриад байх махан биеийн хамаатан садан гэж байхаа болино. Үүргээ биелүүлдэг хүмүүс бол биелүүлдэггүй

хүмүүсийн дайсан; Бурханыг хайрладаг хүмүүс болон Бурханыг үзэн яддаг хүмүүс бол өөр хоорондоо эсрэг хүмүүс. Амралтад орох хүмүүс болон устгагдсан байх хүмүүс нь хоорондоо таарамжгүй хоёр төрлийн бүтээл юм. Үүргээ биелүүлдэг бүтээл амьд үлдэж чадна, харин үүргээ биелүүлдэггүй бүтээл сүйрлийн бай болно; үүнээс гадна, энэ нь мөнхөд үргэлжилнэ. Чи бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлэхийн тулд нөхрөө хайрладаг уу? Мөн бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлэхийн тулд эхнэрээ хайрладаг уу? Бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлэхийн тулд чи үл итгэгч эцэг эхдээ ачлалтай байдаг уу? Бурханд итгэх тухай хүний үзэл бодол зөв үү, буруу юу? Чи яагаад Бурханд итгэдэг юм бэ? Юу олж авахыг хүсдэг юм бэ? Бурханыг хэрхэн хайрладаг вэ? Бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлж чаддаггүй, бүрэн дүүрэн хичээл зүтгэл гаргаж чаддаггүй хүмүүс сүйрлийн бай болно. Өнөөдрийн хүмүүс хоорондоо бие махбодын харилцаатай, түүнчлэн цусан холбоотой байдаг боловч ирээдүйд энэ бүгд нуран унана. Итгэгчид, үл итгэгчид нь хоорондоо таарамжгүй; харин ч нэг нэгнийхээ эсрэг байдаг. Амралтад байгаа хүмүүс Бурхан бий гэдэгт итгэн, Бурханд дуулгавартай байна, харин Бурханд тэрслүү хүмүүс бүгд устгагдсан байх болно. Газар дэлхий дээр гэр бүлүүд оршин байхаа болино; эцэг эх, үр хүүхэд, хань ижлийн харилцаа яаж байж болох юм бэ? Чухамдаа итгэгчид болон үл итгэгчдийн үл нийцэх байдал нь ийм бие махбодын харилцааг бүрмөсөн тасалсан байх болно!

Анх хүн төрөлхтний дунд гэр бүл гэж байгаагүй; эрэгтэй, эмэгтэй буюу хоёр өөр төрлийн хүн л оршин байсан. Гэр бүлүүд байх нь бүү хэл, ямар ч улс орон байгаагүй, харин хүний завхралын улмаас төрөл бүрийн хүмүүс тусдаа овгууд болон зохион байгуулагдаж, дараа нь улс орон, үндэстэн ястан болон хөгжсөн юм. Энэ улс орон, үндэстэн ястан нь тусдаа жижиг гэр бүлүүдээс бүрдэн, ийм маягаар бүх төрлийн хүмүүс хэлний ялгаа, хил хязгаарт үндэслэн янз бүрийн угсаатан ястан болж хуваагдсан билээ. Үнэндээ дэлхий дээр хэчнээн үндэс угсаа байх нь хамаагүй, хүн төрөлхтөн цорын ганц өвөг дээдэстэй. Эхэндээ ердөө хоёр төрлийн л хүн байсан ба энэ хоёр төрөл нь эрэгтэй, эмэгтэй хүн байв. Гэвч Бурханы ажлын ахиц дэвшил, түүхийн замнал, газар зүйн өөрчлөлтийн улмаас энэхүү хоёр төрлийн хүн янз бүрийн түвшинд, улам олон төрлийн хүмүүс болж хөгжээ. Үндсэндээ, хүн төрөлхтөн хэчнээн олон төрлийн үндэс угсаанаас бүрддэг бай хамаагүй, бүх хүн төрөлхтөн Бурханы бүтээл хэвээр юм. Хүмүүс ямар ч үндэс угсаанд харьяалагддаг бай, бүгд Түүний бүтээл мөн; тэд бүгд Адам, Евагийн үр удам билээ. Тэд хэдий Бурханы гараар бүтээгдээгүй ч Бурханы биечлэн бүтээсэн Адам, Евагийн үр удам юм. Хүмүүс ямар төрлийн оршихуйд харьяалагддаг нь хамаагүй, бүгд Түүний бүтээл мөн; тэд Бурханы бүтээсэн хүн төрөлхтөнд харьяалагддаг тул тэдний хүрэх газар нь хүн төрөлхтөнд байх ёстой зүйл бөгөөд хүмүүсийг зохион байгуулдаг дүрмийн дагуу тэд хуваагдсан. Өөрөөр хэлбэл, мууг үйлдэгчид болон зөв шударга хүмүүс нь бүгд эцсийн эцэст бүтээлүүд юм. Ёрын мууг үйлддэг бүтээлүүд эцэстээ устгагдаж, зөв шударга үйл хийдэг бүтээлүүд амьд үлдэнэ. Энэ хоёр төрлийн

бүтээлд зориулсан хамгийн тохиромжтой зохицуулалт энэ юм. Мууг үйлдэгчид дуулгаваргүй байдлаасаа болоод Бурханы бүтээл гэдгээ үгүйсгэж чаддаггүй ч Сатанд олзлогдсон тул аврагдаж чадахгүй. Зөв шударгаар биеэ авч явдаг бүтээлүүд нь, амьд үлдэнэ гэх баримтдаа үндэслэн Бурханаар бүтээгдсэн ч Сатанаар завхруулагдсаныхаа дараа аврал хүлээн авсан гэдгээ үгүйсгэж чадахгүй. Мууг үйлдэгчид бол Бурханд дуулгаваргүй бүтээлүүд; тэд аврагдаж чадахгүй, Сатанд аль хэдийн бүрэн олзлогдсон бүтээлүүд юм. Мууг үйлддэг хүмүүс ч бас хүмүүс; тэд бол туйлын их завхарсан, аврагдаж чадахгүй хүмүүс юм. Зөв шударгыг үйлддэг хүмүүс ч бас бүтээл учраас мөн л завхарсан, гэхдээ тэд бол завхарсан зан чанараасаа ангижрахыг хүсдэг хүмүүс бөгөөд Бурханыг дуулгавартай дагах чадвартай болсон. Зөв шударга үйлдэлтэй хүмүүс зөв шударга байдлаар бялхдаггүй; харин ч тэд аврал хүртэж, завхарсан зан чанараасаа ангижирсан; мөн Бурханд дуулгавартай байж чаддаг. Эцэстээ тэд бат зогсоно, гэхдээ энэ нь, тэднийг Сатан завхруулаагүй гэсэн үг биш юм. Бурханы ажил дууссаны дараа Түүний бүх бүтээл дунд устгагдах хүмүүс, амьд үлдэх хүмүүс гэж байх болно. Энэ нь Түүний удирдлагын ажлын зайлшгүй чиг хандлага юм; хэн ч үүнийг үгүйсгэж чадахгүй. Мууг үйлдэгчид амьд үлдэхгүй; Бурханд дуулгавартай байж, эцсээ хүртэл дагадаг хүмүүс амьд үлдэх нь тодорхой. Энэ ажил нь хүн төрөлхтний удирдлагын ажил тул үлдэх хүмүүс ба таягдан хаягдах хүмүүс гэж байх болно. Эдгээр нь өөр өөр төрлийн хүмүүсийн өөр өөр төгсгөл бөгөөд Бурханы бүтээлүүдэд зориулсан хамгийн тохиромжтой зохицуулалт юм. Хүн төрөлхтөнд зориулсан Бурханы туйлын зохицуулалт бол гэр бүлгүй, улсын хил хязгааргүй болгохын тулд гэр бүлүүдийг салгаж, үндэстэн ястныг бутаргаж, улсын хил хязгаарыг нураах замаар тэднийг хуваах явдал юм, учир нь хүмүүс эцсийн эцэст нэг өвөг дээдсээс үүсэлтэй бөгөөд Бурханы бүтээл юм. Товчхондоо мууг үйлдэгч бүтээлүүд бүгд устгагдана, Бурханд дуулгавартай бүтээлүүд амьд үлдэнэ. Ийм маягаар амралтын цаг үе ирэхэд ямар ч гэр бүл, улс орон, ялангуяа үндэстэн ястан гэж байхгүй байх болно; ийм төрлийн хүн төрөлхтөн бол хамгийн ариун хүн төрөлхтөн юм. Газар дээрх бүх зүйлийг хүмүүсээр халамжлуулах гэж Адам Ева хоёрыг анх бүтээсэн; хүмүүс анх бүх зүйлийн эзэн байсан. Хүмүүсийг бүтээсэн Еховагийн санаа зорилго нь тэдэнд газар дээр оршин байж, үүн дээрх бүх зүйлийг арчилж халамжлах боломж олгох явдал байв, учир нь хүн анх завхраагүй, мөн мууг үйлдэх чадваргүй байлаа. Гэвч хүмүүс завхралд өртсөнийхөө дараа бүх зүйлийг халамжлагч байхаа больсон. Бурханы авралын зорилго бол хүний энэ чиг үүргийг сэргээж, хүн төрөлхтний анхдагч эрүүл ухаан, анхдагч дуулгавартай байдлыг сэргээх явдал юм; амралтан дахь хүн төрөлхтөн нь Өөрийн авралын ажлаар Бурханы хүрэхээр зорьдог үр дүнгийн яг таг дүрслэл байх болно. Хэдийгээр энэ нь Еден цэцэрлэгийнх шиг амьдрал байхаа болих ч мөн чанар нь ижил байна; хүн төрөлхтөн зүгээр л урьдын завхраагүй хүмүүс байхаа болино, харин завхралд өртөөд, дараа нь аврал хүртсэн хүн төрөлхтөн байх болно. Аврал хүртсэн энэ хүмүүс эцэстээ (өөрөөр хэлбэл, Бурханы

ажил дууссаны дараа) амралтад орно. Үүний адилаар, шийтгүүлэх хүмүүсийн төгсгөл ч бас эцэстээ бүрмөсөн илчлэгдэж, Бурханы ажил дууссаны дараа л тэд устгагдана. Өөрөөр хэлбэл, Түүний ажил дууссаны дараа мууг үйлдэгчид болон аврагдсан хүмүүс бүгд илчлэгдэнэ, учир нь бүх төрлийн хүмүүсийг (мууг үйлдэгч ч бай, аврагдсан хүмүүс ч бай) илчлэх ажил хүн бүр дээр нэгэн зэрэг хийгдэнэ. Мууг үйлдэгчид таягдан хаягдах ба үлдэж чадах хүмүүс нэгэн зэрэг илчлэгдэнэ. Тиймээс бүх төрлийн хүмүүсийн төгсгөл нэг дор илчлэгдэнэ. Бурхан аврал хүртсэн бүлэг хүмүүсийг амралтад оруулаад, дараа нь мууг үйлдэгчдийг хойш тавьж, тэднийг бага багаар шүүж, эсвэл шийтгэхгүй; тэгэх нь баримтуудтай нийцэхгүй. Мууг үйлдэгчид устгагдаж, амьд үлдэж чадах хүмүүс амралтад орох үед орчлон ертөнц даяарх Бурханы ажил дуусна. Ерөөл хүртэх, зовлон амсах хүмүүсийн дунд эрэмбэлсэн дараалал гэж байхгүй; ерөөл хүртэх хүмүүс мөнх амьдарна, харин зовлон амсах хүмүүс мөнхөд мөхнө. Ажлын энэ хоёр үе шат нэгэн зэрэг гүйцэлдэнэ. Дуулгаваргүй хүмүүс байдаг учраас л дуулгавартай хүмүүсийн зөв шударга байдал илчлэгдэнэ, мөн ерөөл хүртсэн хүмүүс байдаг болохоор л ёрын мууг үйлдэгчдийн хорон муу үйлдлийнхээ төлөө амссан зовлон илчлэгдэнэ. Бурхан мууг үйлдэгчдийг ил болгоогүй бол Бурханыг чин сэтгэлээсээ дуулгавартай дагадаг хүмүүс хэзээ ч нар үзэхгүй байх байсан; хэрвээ Бурхан Өөрийг нь дуулгавартай дагадаг хүмүүсийг тохиромжтой хүрэх газарт нь аваачаагүй бол Бурханд дуулгаваргүй хүмүүс зохих цээрлүүлэлтээ хүртэж чадахгүй байх байсан юм. Энэ бол Бурханы ажлын үйл явц. Хэрвээ Тэр мууг шийтгэж, сайныг шагнах энэ ажлыг хийгээгүй бол Түүний бүтээлүүд тус тусын хүрэх газартаа хэзээ ч орж чадахгүй байх байлаа. Хүн төрөлхтөн амралтад ормогц мууг үйлдэгчид устгагдаж, бүх хүн төрөлхтөн зөв замдаа орсон байх болно; төрөл бүрийн хүмүүс гүйцэтгэх ёстой чиг үүргийнхээ дагуу өөрсдийн төрөлтэй хамт байх болно. Энэ л хүн төрөлхтний амралтын өдөр, хүн төрөлхтний хөгжлийн зайлшгүй чиг хандлага байх бөгөөд хүн төрөлхтөн амралтад орох үед л Бурханы агуу, эцсийн ажил үйлс бүрэн дуусна; энэ нь Түүний ажлын сүүлчийн хэсэг байх болно. Энэхүү ажил бүх хүн төрөлхтний махан биеийн доройтмол амьдралыг дуусгана, мөн түүнчлэн завхарсан хүн төрөлхтний амьдралыг төгсгөнө. Тэр үеэс хойш хүмүүс шинэ ертөнцөд орно. Хэдийгээр бүх хүн махан биед амьдрах ч энэ амьдралын мөн чанар нь завхарсан хүн төрөлхтний амьдралаас ихээхэн ялгаатай байна. Энэ оршин тогтнолын ач холбогдол нь завхарсан хүн төрөлхтний оршин тогтнолын ач холбогдлоос ч бас ялгаатай байдаг. Хэдийгээр энэ нь шинэ төрлийн хүний амьдрал биш байх боловч аврал хүртсэн хүн төрөлхтний амьдрал, түүнчлэн хүн чанар, эрүүл ухаанаа эргүүлэн олж авсан амьдрал гэж хэлж болно. Тэд бол нэгэнтээ Бурханд дуулгаваргүй байсан, Бурханаар байлдан дагуулагдаад, дараа нь Бурханаар аврууулсан хүмүүс юм; тэд бол Бурханыг доромжлоод, хожим нь Түүнд гэрчлэл хийсэн хүмүүс билээ. Түүний туршилтыг туулж, амьд үлдсэний дараа, тэдний оршин тогтнол хамгийн учир утгатай оршин тогтнол байна; тэд бол Сатаны өмнө Бурханд гэрчлэл хийсэн

хүмүүс, мөн амьдрахад тохирох хүмүүс билээ. Устгагдах хүмүүс бол Бурханы төлөө гэрчлэлд зогсож чадахгүй хүмүүс бөгөөд амьдрахад тохирохгүй. Тэдний сүйрэл хорон муу үйлдлийнх нь үр дүн байх бөгөөд тийнхүү бүрмөсөн устгагдах нь тэдний хамгийн сайн хүрэх газар юм. Ирээдүйд хүмүүс сайн сайхан ертөнцөд орох үед хүмүүсийн олж авна гэж төсөөлдөг эхнэр нөхөр, эцэг охин, эсвэл эх хүүгийн харилцааны аль нь ч байхгүй байх болно. Тэр үед хүн бүр өөрийнхөө төрлийг дагах ба гэр бүлүүд аль хэдийн нуран унасан байх болно. Бүрэн бүтэлгүйтсэн Сатан хүн төрөлхтнийг дахин хэзээ ч үймүүлэхгүй бөгөөд хүмүүс завхарсан сатанлаг зан чанартай байхаа болино. Дуулгаваргүй тэр хүмүүс аль хэдийн устгагдсан байх ба дуулгавартай хүмүүс л үлдэнэ. Ингэснээр маш цөөхөн гэр бүл л бүрэн бүтэн үлдэнэ; бие махбодын харилцаа хэрхэн оршин тогтносоор байж болох билээ? Хүмүүсийн урьдын махан биеийн амьдрал бүрмөсөн хориглогдоно; хүмүүсийн хоорондох бие махбодын харилцаа яаж оршин тогтнож болох юм бэ? Завхарсан сатанлаг зан чанаргүйгээр, хүний амьдрал өнгөрсөн үеийн хуучин амьдрал байхаа больж, харин ч шинэ амьдрал болно. Эцэг эх нь үр хүүхдээ алдаж, үр хүүхэд нь эцэг эхээ алдана. Нөхөр нь эхнэрээ алдаж, эхнэр нь нөхрөө алдана. Одоо хүмүүс хоорондоо бие махбодын харилцаатай байдаг ч хүн бүрийг амралтад ормогц бие махбодын харилцаа гэж байхаа болино. Ийм хүмүүс л зөв шударга, ариун байдлыг эзэмшинэ; ийм хүмүүс л Бурханд шүтэн мөргөж чадна.

Бурхан хүмүүсийг бүтээж, газар дээр байрлуулаад, тэр үеэс хойш тэднийг удирдсан. Дараа нь Тэр тэднийг аварч, хүн төрөлхтний төлөөх нүглийн тахил болсон. Эцэст нь Тэр мөн л хүн төрөлхтнийг байлдан дагуулж, хүмүүсийг бүхэлд нь аварч, анхдагч төрхийг нь сэргээх ёстой болсон. Хүний анхдагч дүр, анхны төрхийг сэргээх энэхүү ажлыг Тэр бүр эхнээсээ л хийсээр ирсэн. Бурхан хаанчлалаа байгуулж, хүний анхдагч төрхийг сэргээнэ, өөрөөр хэлбэл, Бурхан газар дээр, бүх бүтээлийн дунд эрх мэдлээ сэргээнэ. Сатанаар завхруулагдсаны дараа хүн Бурханаас эмээх зүрх сэтгэлээ алдаж, Бурханы бүтээлд оногдсон чиг үүргээ ч алдаж, улмаар Бурханд дуулгаваргүй дайсан болжээ. Тэгээд хүмүүс Сатаны эзэмшилд амьдарч, Сатаны тушаалыг дагасан; тиймээс Бурхан бүтээлүүдийнхээ дунд ажиллах ямар ч аргагүй болж, тэдний айж эмээсэн хүндлэлийг олж авч бүр ч чадахаа больсон юм. Хүмүүс Бурханаар бүтээгдсэн, Бурханд шүтэн мөргөх учиртай боловч үнэндээ Бурханаас нүүр буруулж, оронд нь Сатаныг шүтжээ. Тэгээд Сатан хүний зүрх сэтгэл дэх шүтээн болов. Ийнхүү Бурхан хүний зүрх сэтгэл дэх байр сууриа алдсан, өөрөөр хэлбэл, Тэр хүнийг бүтээснийхээ утга учрыг алдсан. Тиймээс хүнийг бүтээснийхээ утга учрыг сэргээхийн тулд Тэр хүний анхдагч төрхийг сэргээж, хүнийг завхарсан зан чанараас нь ангижруулах ёстой. Хүмүүсийг Сатанаас буцаан авахын тулд Тэр тэднийг нүглээс аврах ёстой. Ийм маягаар л Бурхан тэдний анхдагч төрх болон чиг үүргийг аажмаар сэргээж, Өөрийн хаанчлалыг сэргээж чадна. Дуулгаваргүй хөвгүүдийн эцсийн сүйрэл нь ч бас, хүмүүсийг Бурханд илүү их шүтэн мөргүүлж, газар дээр илүү сайхан амьдруулахын төлөө хийгдэнэ. Бурхан хүмүүсийг

бүтээсэн тул Тэр хүнийг Өөртөө шүтэн мөргүүлнэ; Тэрээр хүний анхдагч чиг үүргийг сэргээхийг хүсдэг тул ямар ч хольцгүйгээр бүрэн сэргээнэ. Өөрийн эрх мэдлийг сэргээнэ гэдэг нь хүнийг Өөртөө шүтэн мөргүүлж, Өөртөө дуулгавартай байлгана гэсэн үг юм; мөн Бурхан хүмүүсийг Өөрөөсөө үүдэн амьдруулж, дайснаа Өөрийн эрх мэдлээр сүйрүүлнэ гэсэн утгатай. Бас Бурхан, хэний ч эсэргүүцэлгүйгээр Өөрийнхөө бүхий л зүйлийг хүмүүсийн дунд үлдээнэ гэсэн үг юм. Бурханы байгуулахыг хүсдэг хаанчлал бол Түүний Өөрийн хаанчлал билээ. Түүний хүсдэг хүн төрөлхтөн бол Түүнд шүтэн мөргөдөг, Түүнийг бүрэн дуулгавартай дагадаг, Түүний алдар сууг илтгэдэг хүмүүс юм. Хэрвээ Бурхан завхарсан хүн төрөлхтнийг аврахгүй бол хүнийг бүтээснийх нь утга учир алдагдана; Тэрээр хүмүүсийн дунд ямар ч эрх мэдэлгүй байж, Түүний хаанчлал газар дээр оршин тогтнож чадахаа болино. Хэрвээ Бурхан, Өөрт нь дуулгаваргүй байдаг дайснуудаа устгахгүй бол бүрэн алдар суугаа олж авч чадахгүй, газар дээр хаанчлалаа байгуулж ч чадахгүй. Хүн төрөлхтний дундаас Өөрт нь дуулгаваргүй хүмүүсийг бүрмөсөн устгаж, бүрэн төгс болгуулсан хүмүүсийг амралтад аваачих нь Түүний ажил дууссаны тэмдэг, Түүний агуу амжилтын тэмдэг байх болно. Хүмүүс анхдагч төрхөө сэргээж, тус тусын үүргийг гүйцэтгэж, өөрсдийн зүй ёсны байр суурийг хадгалж, Бурханы бүх зохицуулалтад захирагдаж чаддаг байх үед Бурхан, Өөрт нь шүтэн мөргөдөг бүлэг хүмүүсийг газар дээр олж авсан байх бөгөөд Өөрт нь шүтэн мөргөдөг хаанчлалыг ч газар дээр байгуулсан байх болно. Тэр газар дээр мөнхөд ялж, Түүнийг эсэргүүцдэг хүмүүс үүрд мөхнө. Энэ нь хүн төрөлхтнийг бүтээсэн Түүний анхдагч санаа зорилгыг сэргээнэ; энэ нь бүх зүйлийг бүтээсэн Түүний санаа зорилгыг сэргээж, газар дээрх, бүх зүйлийн дундах, дайснуудынх нь дундах Түүний эрх мэдлийг сэргээнэ. Эдгээр нь Түүний бүрэн ялалтын бэлгэ тэмдэг байх болно. Тэр үеэс хойш хүн төрөлхтөн амралтад орж, зөв зам дээрх амьдралыг эхлүүлнэ. Бурхан ч бас хүнтэй хамт мөнхийн амралтад орж, Бурхан, хүн хоёрын хуваалцдаг мөнхийн амьдралыг эхлүүлнэ. Газар дээрх бузар булай болон дуулгаваргүй байдал алга болж, бүхий л уйлаан ч бас үгүй болж, энэ дэлхий дээр Бурханыг эсэргүүцдэг бүхэн оршин тогтнохоо больсон байх болно. Бурхан болон Түүний аварсан хүмүүс л үлдэнэ; Түүний бүтээл л үлдэнэ.

ЧУУЛГАНУУДААР ЯВАХДАА ХРИСТИЙН ХЭЛСЭН ҮГ

IV

(1994—2010 ОНЫ 3-Р САРЫН 23)

ЕСҮСИЙН СҮНСЛЭГ БИЕИЙГ ХАРАХ ҮЕД ЧИНЬ БУРХАН ТЭНГЭР, ГАЗРЫГ ШИНЭЭР БҮТЭЭСЭН БАЙХ БОЛНО

Чи Есүсийг харахыг хүсэж байна уу? Чи Есүстэй хамт амьдрахыг хүсэж байна уу? Чи Есүсийн хэлсэн үгийг сонсохыг хүсэж байна уу? Хэрэв тийм бол чи Есүсийг эргэн ирэхэд хэрхэн угтах вэ? Чи бүрэн бэлтгэсэн үү? Чи Есүсийг эргэн ирэхэд ямар байдлаар угтах вэ? Миний бодлоор Есүсийг дагадаг ах эгч болгон Түүнийг сайхан угтаж авахыг хүсдэг байх. Гэхдээ та нар ер нь ингэж бодож үзсэн үү: Есүсийг эргэн ирэх үед чи Түүнийг үнэхээр мэдэх үү? Түүний хэлсэн бүхнийг та нар үнэхээр ойлгох уу? Түүний хийдэг бүх ажлыг ямар ч болзолгүйгээр үнэхээр хүлээн авах уу? Библийг уншсан бүх хүн Есүс эргэн ирнэ гэдгийг мэддэг ба Библи уншсан бүх хүн Түүний эргэн ирэхийг анхааралтай хүлээдэг. Та бүгд тэр мөч ирэх тухайд л анхаардаг, та нарын үнэнч сэтгэл магтууштай, итгэл үнэмшил чинь үнэхээр атаархмаар, гэвч та нар ноцтой алдаа гаргаснаа ухаарсан уу? Есүс ямар байдлаар эргэн ирэх вэ? Есүсийг цагаан үүлэн дээр эргэн ирнэ гэдэгт та нар итгэдэг, гэхдээ Би та нараас асууя: Энэ цагаан үүл гэдэг нь юуг хэлдэг вэ? Өөрийнх нь эргэн ирэхийг маш олон дагагч нь хүлээж байхад Есүс ямар хүмүүсийн дунд бууж ирэх вэ? Есүс хамгийн түрүүнд та нарын дунд бууж ирвэл бусад нь үүнийг тун шударга бус гэж үзэх бус уу? Есүсийн төлөө гэсэн агуу чин сэтгэлтэй, үнэнч гэдгийг чинь Би мэдэж байна. Гэхдээ та нар Есүстэй ер нь уулзаж байсан уу? Та нар Түүний зан чанарыг мэдэх үү? Та нар ер нь Түүнтэй цуг амьдарч байсан уу? Та нар Түүний талаар үнэндээ хэр их ойлгодог вэ? Эдгээр үг өөрсдийг нь эвгүй байдалд орууллаа гэж зарим нь хэлнэ. Тэд: “Би Библийг эхнээс нь дуустал маш олон удаа уншсан. Би яаж Есүсийг ойлгож чадахгүй байх юм бэ? Есүсийн зан чанар байтугай, өмсөх дуртай байсан хувцасных нь өнгийг хүртэл би мэднэ. Намайг Та Түүнийг ойлгодоггүй гэж хэлэхдээ намайг басамжилж байгаа хэрэг биш үү?” гэх байх. Гэхдээ эдгээр асуудлаар маргах хэрэггүй гэж чамд Би зөвлөе; чи тайвшраад дараах асуултуудын талаар нөхөрлөсөн нь дээр: Нэгдүгээрт, чи бодит байдал гэж юу болохыг, мөн онол гэж юу болохыг мэдэх үү? Хоёрдугаарт, чи үзэл гэж юу болохыг болон үнэн гэж юу болохыг мэдэх үү? Гуравдугаарт, чи төсөөлөл гэж юу болохыг, бодит зүйл гэж юу болохыг мэдэх үү?

Зарим хүн Есүсийг ойлгодоггүй гэдгээ үгүйсгэдэг. Гэхдээ л та нар Түүнийг өчүүхэн ч гэсэн ойлгодоггүй, мөн Есүсийн ганц ч үгийг ойлгодоггүй гэж Би хэлдэг. Яагаад гэвэл, та нар дор бүрнээ Библийн тэмдэглэлүүд, мөн бусдын хэлсэн зүйлээс болж Түүнийг дагадаг. Та нар Есүсийг хэзээ ч харж байгаагүй, цуг амьдарч ч байгаагүй, Түүнтэй түр зуур ч хамт байгаагүй. Иймд Есүсийн талаарх та нарын ойлголт ердөө л онол төдий биш гэж үү? Энэ чинь бодит байдалгүй бус уу? Зарим хүн Есүсийн хөргийг харсан, эсвэл Есүсийн гэрт биечлэн очиж байсан байх. Магадгүй зарим нь Есүсийн хувцсанд хүрч байсан байх. Гэхдээ чи Есүсийн

идсэн хоолыг биечлэн амссан байсан ч гэсэн, Түүний талаарх ойлголт чинь бодитой бус, онолынх хэвээр байдаг. Ямар ч тохиолдолд чи Есүсийг хараагүй, Түүний махбодтой хамт байгаагүй бол Есүсийн талаарх ойлголт чинь үргэлж бодит байдлаас тасархай, хоосон онол хэвээр байна. Миний үг чамд жаахан сонирхолгүй байж магад, тэгвэл Би чамаас ингэж асууя: Чи хамгийн их биширдэг зохиолчийнхоо олон бүтээлийг уншсан байж болох ч цагийг хамтдаа өнгөрүүлэлгүйгээр түүнийг бүрэн ойлгож чадах уу? Зан араншин нь ямрыг чи мэдэх үү? Ямаршуу амьдардгийг нь мэдэх үү? Сэтгэл санааных нь байдлын талаар ямар нэг зүйл мэдэх үү? Чи биширдэг хүнээ ч бүрэн ойлгож чадахгүй байгаа атлаа Есүс Христийг яаж ойлгож чадах юм бэ? Есүсийн талаар чиний мэдэх бүх зүйл ямар ч үнэн, бодит зүйлгүй, бүхэлдээ үзэл, төсөөлөл юм. Энэ чинь өмхий, бас махан биеэр дүүрэн. Ийм ойлголт яаж чамайг Есүсийг эргэн ирэх үед угтаж авах эрхтэй болгох вэ? Уран зөгнөл, махан биеийн үзлээр дүүрэн хүмүүсийг Есүс хүлээж авахгүй. Есүсийг ойлгодоггүй хүмүүс яаж Түүнд итгэгчид байхад тохирох билээ?

Фарисайчууд Есүсийг эсэргүүцсэний уг шалтгааныг та нар мэдмээр байна уу? Фарисайчуудын мөн чанарыг мэдэхийг хүсэж байна уу? Тэд Мессиагийн талаарх уран зөгнөлөөр дүүрэн байсан. Үүнээс гадна, тэд Мессиа ирнэ гэдэгт л итгэсэн ч амь-үнэнийг эрэлхийлээгүй. Иймээс өнөөдөр ч гэсэн тэд Мессиаг хүлээсээр л байдаг, учир нь тэдэнд амийн замын талаар ямар ч мэдлэг байдаггүй, мөн үнэний зам гэж юу болохыг мэддэггүй. Ийм мунхаг, зөрүүд, мэдлэггүй хүмүүс Бурханы ерөөлийг олж авч чадах уу, та нар хэл дээ? Тэд яаж Мессиаг харж чадах юм бэ? Тэд Ариун Сүнсний ажлын чиглэлийг мэдээгүй, Есүсийн хэлсэн үнэний замыг мэдээгүй, түүнчлэн Мессиаг ойлгоогүй учраас Есүсийг эсэргүүцсэн. Тэд Мессиаг хэзээ ч харж байгаагүй, Мессиатай хэзээ ч хамт байгаагүй болохоор Мессиагийн нэр төдийхөнтэй зууралдах зуураа Мессиагийн мөн чанарыг боломжит бүх аргаар эсэргүүцэх алдаа гаргасан. Энэ фарисайчууд мөн чанарын хувьд зөрүүд, биеэ тоосон, үнэнийг дуулгавартай дагаагүй. Тэдний Бурханд итгэх зарчим нь энэ: Таны номлол хэр гүн гүнзгий, Таны эрх мэдэл хэчнээн өндөр дээд ч бай, Мессиа гэж нэрлэгдээгүй л бол Та Христ биш. Тэдний энэ итгэл нь утгагүй, хөгийн биш гэж үү? Би та нараас цааш нь асууя: Та нарт Есүсийн талаар өчүүхэн ч ойлголт байхгүй юм чинь эрт үеийн фарисайчуудын алдааг гаргах нь туйлын хялбар биш гэж үү? Чи үнэний замыг ялган таньж чадах уу? Чи Христийг эсэргүүцэхгүй гэдгээ үнэхээр баталж чадах уу? Чи Ариун Сүнсний ажлыг дагаж чадах уу? Чи Христийг эсэргүүцэх эсэхээ мэдэхгүй байвал аль хэдийн үхлийн ирмэгт амьдарч байна гэж Би хэлнэ. Мессиаг мэддэггүй хүмүүс бүгд Есүсийг эсэргүүцэж, голж, гүжирдэх чадвартай байсан. Есүсийг ойлгодоггүй хүмүүс бүгд Түүнийг голж, доромжлох боломжтой. Түүнчлэн тэд Есүсийн эргэн ирэлтийг Сатаны заль мэх гэж харах боломжтой ба махбодоор эргэн ирсэн Есүсийг илүү олон хүн яллах болно. Энэ бүх зүйл та нарыг айлгахгүй байна гэж үү? Ариун Сүнсийг доромжилж, чуулгануудад хэлсэн Ариун

Сүнсний үгийг сүйрүүлж, Есүсийн илэрхийлсэн бүхнийг голох явдалтай та нар нүүр тулна. Та нар ийм мунгинуу байвал Есүсээс юу олж авч чадах юм бэ? Хэрвээ та нар алдаагаа ойлгохоос зөрүүдлэн татгалзаж байгаа бол Есүсийг цагаан үүлэн дээр махбодоор эргэн ирэх үед Есүсийн ажлыг яаж ойлгож чадах юм бэ? Би та нарт үүнийг хэлье: Үнэнийг хүлээн авдаггүй атлаа Есүс цагаан үүлэн дээр ирэхийг сохроор хүлээдэг хүмүүс Ариун Сүнсийг гарцаагүй доромжлох бөгөөд тэд бол устгагдах төрөл мөн. Та нар ердөө л Есүсийн нигүүлслийг хүсэж, тэнгэрийн жаргалтай ертөнцөд жаргахыг хүсдэг, гэсэн атлаа Есүсийн хэлсэн үгийг хэзээ ч дуулгавартай дагаж байгаагүй, махбодоор эргэн ирэх үедээ хэлсэн үнэнийг нь хэзээ ч хүлээн аваагүй. Есүс цагаан үүлэн дээр эргэн ирэх тухай баримтын хариуд та нар юу өргөн барих вэ? Удаа дараа нүгэл үйлдэж, үүнийгээ ахин дахин улайх чин сэтгэл үү? Цагаан үүлэн дээр эргэн ирэх Есүст та нар юуг тахил болгон өргөх вэ? Өөрсдийгөө өргөмжилдөг олон жилийн ажлаа юу? Эргэн ирсэн Есүсийг өөрсдөдөө итгүүлэхийн тулд та нар юу өргөн барих вэ? Ямар ч үнэнийг дуулгавартай дагадаггүй, биеэ тоосон уг чанараа юу?

Та нар үгээрээ л үнэнч байдаг, та нарын мэдлэг танин мэдэхүй, үзэл баримтлал төдий байдаг, та нарын хөдөлмөр тэнгэрийн ерөөлийг олж авахын төлөө байдаг, тэгвэл итгэл чинь ямар болж таарах вэ? Өнөөдөр ч гэсэн та нар үнэний үг нэг бүрийг чихнийхээ хажуугаар өнгөрөөдөг. Та нар Бурхан гэж юу болохыг, Христ гэж хэн болохыг мэддэггүй, Еховаг хэрхэн хүндэтгэхийг мэддэггүй, Ариун Сүнсний ажилд хэрхэн орохыг мэддэггүй, Бурханы Өөрийн ажил болон хүний мэхлэлтийг хэрхэн ялгахаа мэддэггүй. Чи Бурханы илэрхийлсэн, бодолтой чинь нийцдэггүй үнэний үгийг яллахаа л мэддэг. Даруу байдал чинь хаана байна вэ? Дуулгавартай байдал чинь хаана байна вэ? Үнэнч байдал чинь хаана байна вэ? Үнэнийг эрж хайх хүсэл чинь хаана байна вэ? Бурханыг хүндлэх хүндлэл чинь хаана байна вэ? Би та нарт хэлье, тэмдгийн улмаас Бурханд итгэдэг хүмүүс бол гарцаагүй устгагдах ангилалд багтдаг. Махбодоор эргэн ирсэн Есүсийн үгийг хүлээн авч чаддаггүй хүмүүс бол гарцаагүй тамын үр удам, тэргүүн тэнгэрэлчийн үр хойч, мөнхийн сүйрэлд өртөх төрөл юм. Олон хүн Миний хэлсэн зүйлийг тоохгүй байж магад, гэвч Есүс тэнгэрээс цагаан үүлэн дээр бууж ирэхийг хоёр нүдээрээ харах үед чинь зөвт байдлын Нар олон нийтэд үзэгдэнэ гэдгийг Би Есүсийг дагадаг ариун хүмүүс гэгддэг хүн бүрд хэлэхийг хүсэж байна. Магадгүй тэр нь чиний хувьд маш сэтгэл догдлом мөч байж болох ч Есүс тэнгэрээс буун ирж буйг нүдээр үзэх тэр үе бол бас шийтгүүлэхээр там руу буух үе чинь гэдгийг мэдэх хэрэгтэй. Энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийн цаг үе байх бөгөөд Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэх үе байх болно. Учир нь, хүн тэмдгийг харахаас өмнө, үнэний илэрхийлэл л байх үед Бурханы шүүлт дууссан байх болно. Үнэнийг хүлээн авдаг, тэмдгийг эрж хайдаггүй хүмүүс ариусаж, Бурханы сэнтийн өмнө эргэн ирж, Бүтээгчийн тэвэрт орсон байх болно. “Цагаан үүл хөлөглөн ирээгүй Есүс бол хуурамч Христ” хэмээн муйхарлан итгэдэг хүмүүс

мөнхийн шийтгэл хүртэнэ, учир нь тэд тэмдэг үзүүлдэг Есүст л итгэдэг, харин хатуу шүүлт зарлан, амийн үнэн замыг гаргадаг Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгэхээр Есүс цагаан үүлэн дээр ил тодоор эргэн ирэх үедээ л үүнийг шийдвэрлэх болно. Тэд хэтэрхий зөрүүд, өөртөө итгэлтэй, биеэ тоосон. Иймэрхүү өөдгүй хүмүүс яаж Есүсээр шагнуулж чадах билээ? Есүс эргэн ирнэ гэдэг нь үнэнийг хүлээн авч чаддаг хүмүүсийн хувьд агуу аврал, тэгж чаддаггүй хүмүүсийн хувьд яллалтын тэмдэг юм. Та нар өөрсдийн замыг сонгох хэрэгтэй ба Ариун Сүнсийг доромжилж, үнэнийг голох ёсгүй. Та нар юм мэдэхгүй, биеэ тоосон хүн байх бус, харин Ариун Сүнсний удирдамжийг дуулгавартай дагаж, үнэнийг хүсэн хүлээж, эрж хайдаг хүн байх хэрэгтэй; ийм байдлаар л та нар ашиг тус хүртэх болно. Би та нарт Бурханд итгэх замаар хянуур явахыг зөвлөж байна. Дүгнэлт хийх гэж бүү яар; түүнчлэн, Бурханд итгэх итгэлдээ хайхрамжгүй, бодлогогүй бүү бай. Бурханд итгэдэг хүмүүс ядаж даруу агаад хүндлэлтэй байх ёстой гэдгийг та нар мэдэх хэрэгтэй. Үнэнийг сонссон хэр нь хямсганадаг хүмүүс бол мунхаг, мэдлэггүй хүмүүс юм. Үнэнийг сонссон мөртөө хайхрамжгүйгээр дүгнэлт хийх гэж яардаг, эсвэл үнэнийг ялладаг хүмүүс биеэ тоосон байдаг. Есүст итгэдэг хэн ч бай бусдыг харааж, яллах эрхгүй. Та нар бүгд эрүүл ухаантай, үнэнийг хүлээн авдаг хүмүүс байх хэрэгтэй. Магадгүй үнэний замыг сонсож, амийн үгийг уншаад, энэ 10,000 үгээс ганц нь л чиний бодол санаа болон Библитэй нийцэж байна гэж бодвол энэ 10,000 үгээс ганцыг нь чи цааш эрж хайх хэрэгтэй. Өөртөө хэт итгэлтэй байж, өөрийгөө хэт өндөрт өргөмжлөлгүйгээр даруу байхыг Би чамд бас зөвлөе. Бурханыг өчүүхэн төдий хүндэтгэх зүрх сэтгэлтэй бол чи илүү их гэрлийг олж авна. Чи эдгээр үгийг анхааралтай шинжилж, ахин дахин тунгаавал эдгээр нь үнэн мөн эсэх, амь мөн эсэхийг ойлгох болно. Магадгүй зарим хүн цөөн хэдэн өгүүлбэр уншчихаад л эдгээр үгийг сохроор яллаж, “Энэ чинь Ариун Сүнсний бага зэрэг гэгээрлээс цаашгүй юм байна” эсвэл “Энэ бол хүмүүсийг төөрөлдүүлэх гэж ирсэн хуурамч Христ байна” гэж хэлнэ. Ингэж хэлдэг хүмүүс мэдлэггүй байдалдаа сохорсон байдаг. Чи Бурханы ажил, мэргэн ухааны талаар хэтэрхий өчүүхэн ойлголттой тул чамд Би дахиад эхнээс нь эхэл гэж зөвлөж байна! Та нар эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд илэрдэг гээд Бурханы хэлсэн үгийг сохроор яллах ёсгүй, залилуулахаас айсандаа Ариун Сүнсийг доромжилдог нэгэн байх ёсгүй. Тэгвэл асар харамсалтай бус уу? Ихээхэн судалж шинжилснийхээ дараа ч чи эдгээр үг нь үнэн биш, зам биш, Бурханы илэрхийлэл биш гэж бодсоор байвал эцэстээ шийтгүүлж, ямар ч ерөөлгүй хоцорно. Хэрэв чи ийм тодорхой, илэн далангүй хэлсэн үнэнийг хүлээн авч чадахгүй бол Бурханаар аврууулахад тохирохгүй бус уу? Чи Бурханы сэнтийн өмнө эргэн очих ерөөлгүй хүн биш гэж үү? Бодоод үз! Бодлогогүй, хуумгай бүү бай, Бурханд итгэх итгэлд тоглоом мэт бүү ханд. Хүрэх газрынхаа төлөө, хэтийн ирээдүйнхээ төлөө, амийнхаа төлөө бод, мөн өөрөөрөө бүү тогло. Чи эдгээр үгийг хүлээн авч чадах уу?

ХРИСТТЭЙ НИЙЦДЭГГҮЙ ХҮМҮҮС ГАРЦААГҮЙ БУРХАНЫГ ЭСЭРГҮҮЦЭГЧИД ЮМ

Бүх хүн Есүсийн жинхэнэ төрхийг харахыг хүсдэг бөгөөд бүгд Түүнтэй хамт байхыг хүсдэг. Ах эгч нарын хэн нь ч Есүсийг харахыг эсвэл Түүнтэй хамт байхыг хүсдэггүй гэж хэлэхгүй байх хэмээн Би бодож байна. Есүсийг харахаасаа өмнө, бие махбодтой болсон Бурханыг харахаасаа өмнө магад та нар Есүсийн илрэлт, ярьж байгаа байдал, амьдралын хэв маяг гэх мэтийнх нь талаар төрөл бүрийн санаа бодол тээж байдаг. Гэвч Түүнийг үнэхээр харах үед та нарын санаа бодол даруй өөрчлөгдөнө. Яагаад тэр вэ? Та нар мэдэхийг хүсэж байна уу? Хүний бодлыг үл тоомсорлож болохгүй гэдэг нь үнэн боловч түүнээс ч илүүтэйгээр Христийн мөн чанарыг хүн өөрчлөхийг тэвчишгүй. Та нар Христийг үхэшгүй мөнх, эсвэл мэргэн хүн гэж боддог боловч хэн ч Түүнийг бурханлаг мөн чанартай ердийн хүн гэж үздэггүй. Тиймээс Бурханыг харахаар өдөр шөнөгүй хүсэмжилж байдаг олон хүн үнэндээ Бурхантай дайсагнадаг бөгөөд Түүнтэй нийцдэггүй. Энэ нь хүний гаргадаг алдаа бус уу? Христийн дүр төрхийг харах гавьяатай нэгэн болоход итгэлтэй, үнэнч байгаа маань л хангалттай гэж та нар одоо ч гэсэн боддог, гэвч өөрсдийгөө илүү их бодитой зүйлсээр зэвсэглэхийг Би та нарт захиж байна! Яагаад гэвэл, өнгөрсөн, одоо, ирээдүйд Христтэй уулзаж учирч байсан хүмүүсийн ихэнх нь бүтэлгүйтсэн эсвэл бүтэлгүйтэх болно; тэд бүгд фарисайчуудын үүрэг гүйцэтгэдэг. Та нарын бүтэлгүйтсэн шалтгаан юу вэ? Гол нь та нарын үзэлд сүрдэм, гайхан биширмээр Бурхан байдгаас л улбаатай юм. Гэхдээ бодит үнэн хүний хүссэнтэй адилгүй. Христ сүрдэм биш байгаад зогсохгүй, харин бүр ч жижигхэн; Тэр хүн, тэр тусмаа бүр жирийн л нэг хүн; Тэр тэнгэр өөд гарч чадах нь байтугай газар дээр эрх чөлөөтэй явж ч чаддаггүй. Ийм болохоор хүмүүс Түүнд жирийн хүнд ханддаг шигээ ханддаг; тэд Түүнтэй хамт байхдаа Түүнд хайнга хандаж, Түүнтэй хайхрамжгүй ярьж, тэр зууpаа “жинхэнэ Христийн” ирэхийг хүлээсээр байдаг. Аль хэдийн ирчхээд байгаа Христийг та нар жирийн хүн гэж тооцдог бөгөөд Түүний үгийг жирийн хүний үг гэж үздэг. Энэ шалтгааны улмаас та нар Христээс юу ч аваагүй, харин оронд нь өөрсдийн муу муухай байдлыг гэрэлд бүрэн ил гаргасан.

Христтэй уулзахаасаа өмнө магад чи, зан чанараа бүрэн өөрчлөгдсөн, өөрийгөө Христийн үнэнч дагагч, Христийн ерөөлийг хүлээн авах чамаас илүү гавьяатай хүн өөр байхгүй бөгөөд олон замаар явж, ихээхэн ажил хийж, их үр дүн гаргасан болохоороо эцэст нь титэм хүлээн авах хүмүүсийн нэг болох нь гарцаагүй хэмээн итгэдэг. Гэвч чиний мэддэггүй байж болох нэг бодит үнэн бий: Христийг харах үед хүний завхарсан зан чанар болон тэрслүү байдал, эсэргүүцэл нь ил болдог бөгөөд тэр үед ил болдог тэрслүү байдал, эсэргүүцэл нь хэзээ хэзээнийхээс ч илүү бүрэн дүүрэн, бүхэлдээ илчлэгддэг. Учир нь Христ бол хүний Хүү—хэвийн хүн чанартай, хүний Хүү учраас хүн Түүнийг дээдэлдэг ч үгүй, мөн хүндэлдэг ч үгүй. Бурхан махбодод амьдардаг болохоор л хүний тэрслүү байдал нэгд нэггүй агаад

тийм тод томруунаар ил болсон. Иймээс Христийн ирэлт нь хүн төрөлхтний бүх тэрслүү байдлыг ухан гаргаж, хүн төрөлхтний уг чанарыг илэрхий болгосон гэж Би хэлдэг. Үүнийг “барыг уулнаас буулгах” болон “чоныг үүрнээс нь гаргах” гэж нэрлэдэг. Чи өөрийгөө Бурханд үнэнч гэж хэлж зүрхлэх үү? Бурханд туйлын дуулгавартай байдаг гэж чи хэлж зүрхлэх үү? Чи тэрслүү биш гэж хэлж зүрхлэх үү? Зарим хүн, “Бурхан намайг шинэ орчинд оруулах болгонд би дургүйцэн бувтнахгүйгээр байнга захирагддаг, цаашлаад би Бурханы талаар ямар ч үзэл тээдэггүй” гэдэг. Зарим нь, “Бурхан надад ямар ч ажил өгсөн бай, би чадлынхаа хэрээр хийдэг, хэзээ ч хуумгай ханддаггүй” гэж хэлнэ. Тэгвэл Би та нараас ингэж асууя: Та нар Христтэй хамт амьдрахдаа Түүнтэй нийцэлтэй байж чадах уу? Та нар хэр удаан Түүнтэй нийцэлтэй байх вэ? Нэг өдөр үү? Хоёр өдөр үү? Нэг цаг уу? Хоёр цаг уу? Та нарын итгэлийг магтууштай байж болох ч тууштай байдал та нарт нэг их байдаггүй. Чи Христтэй жинхэнээсээ хамт амьдрах үед өөрийгөө зөвтгөдөг, өөрийгөө чухалчилдаг зан чинь чиний үг, үйлдлээр дамжуулан бага багаар илчлэгддэг бөгөөд та нарын бардамнах хүсэл, дуулгаваргүй сэтгэлгээ, сэтгэл дундуур байдал ч бас аяндаа илчлэгдэнэ. Эцэст нь чиний биеэ тоосон зан улам нэмэгдсээр Христтэй гал ус мэт зөрчилдөх хэмжээнд хүрэхэд уг чанар чинь бүрэн ил болно. Тэр үед чиний үзэл далдлагдахаа больж, гомдол чинь ч гэсэн аяндаа ил гарах бөгөөд олиггүй хүн чанар чинь бүрэн ил болно. Гэхдээ тэр үед ч гэсэн чи тэрслүү байдлаа хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй, харин оронд нь ийм Христийг хүн хүлээн зөвшөөрөхөд амаргүй, Тэр хүнд хэтэрхий хатуу ханддаг, хэрвээ илүү эелдэг зөөлөн Христ байсан бол Түүнд бүрэн захирагдах байсан юм гэж итгэдэг. Та нар тэрслүү байдлаа зөвтгөх шалтгаантай, тэвчээрийг чинь барах үед л та нар Түүний эсрэг тэрсэлдэг гэж итгэдэг. Христийг Бурхан гэж үздэггүй, Түүнийг дуулгавартай дагах бодолгүй байдаг тухайгаа та нар хэзээ ч бодож байгаагүй. Тэгсэн мөртөө чи Христээс хүслийнхээ дагуу ажиллахыг муйхарлан шаарддаг бөгөөд Түүнийг нэг л зүйлийг чиний бодсоноос өөрөөр хиймэгц Түүнийг Бурхан биш, харин хүн юм байна гэж чи итгэдэг. Ийм маягаар Түүнтэй тэмцэлдсэн хүн та нарын дунд олон байдаггүй гэж үү? Эцсийн эцэст та нар хэнд итгэдэг юм бэ? Та нар ямар байдлаар эрж хайдаг вэ?

Та нар Христийг харахыг үргэлж хүсдэг, гэхдээ өөрсдийгөө ингэж өндрөөр үнэлэх хэрэггүй гэж Би та нарыг ятгах байна. Хүн бүр Христийг харж болох боловч хэн ч Христийг харахад тохирохгүй гэж Би хэлдэг. Хүний уг чанар нь ёрын муу, биеэ тоосон зан, тэрслүү байдлаар дүүрэн учраас Христийг харах мөчид уг чанар чинь чамайг үгүй хийж, үхлээр яллах болно. Ахтай (эсвэл эгчтэй) харилцах харилцаа чинь чиний талаар ихийг өгүүлэхгүй байж болно, гэвч Христтэй харилцах үед тийм ч амар байхгүй. Хэзээ ч хамаагүй үзэл чинь үндэслэж, биеэ тоосон зан чинь соёолж, тэрслүү байдал чинь инжрээр жимсэлж болзошгүй. Иймэрхүү хүн чанартай байж чи Христтэй харилцахад хэрхэн тохирох билээ? Өдөр болгоны хором бүрд чи Түүнд Бурхан гэж хандаж үнэхээр чадах уу? Бурханд

захирагдах бодит байдал чамд үнэхээр бий юү? Та нар өөрийнхөө зүрх сэтгэл дэх өндөр дээд Бурханыг Ехова гэж шүтэн мөргөдөг хэр нь нүднээ илхэн Христийг хүн гэж үздэг. Та нарын эрүүл ухаан дэндүү дорд, хүн чанар чинь дааНч дорой ажээ! Та нар Христийг үргэлж Бурхан гэж үзэх чадваргүй; хааяа хааяахан дураа хүрэх үедээ л Түүнийг барьж аваад, Бурхан гэж шүтэн мөргөх бөлгөө. Тийм учраас Би та нарыг Бурханы итгэгчид биш, харин Христийг эсэргүүцдэг бүлэг хамсаатан гэж хэлж байгаа юм. Бусдад сайхан сэтгэл гаргадаг хүмүүсийн ч ачийг хариулдаг байтал та нарын дунд ийм ажил хийсэн Христ, хүний хайрыг ч хүлээсэнгүй, хүнээс хариу төлөөс, дуулгавартай байдлыг ч хүлээн авсангүй. Энэ нь сэтгэл өвтгөм зүйл биш гэж үү?

Чи олон жил Бурханд итгэж, хэзээ ч хэнийг ч хараагаагүй, эсвэл нэг ч муу үйл үйлдээгүй байж магадгүй, гэхдээ Христтэй харилцахдаа чи үнэнийг ярьж, үнэнч шударга зан гаргаж, эсвэл Христийн үгийг дуулгавартай дагаж чаддаггүй; тийм болохоор Би чамайг дэлхий дээрх хамгийн хорон муу, хорлонтой хүн гэж хэлдэг юм. Чи хамаатан садан, найз нөхөд, эхнэр (эсвэл нөхөр), хөвгүүд охид, эцэг эхдээ гойд найрсаг, үнэнч хайртай байж, бусдыг хэзээ ч завшиж байгаагүй байж болох боловч, хэрвээ чи Христтэй нийцэлтэй байх чадваргүй, эв зохицолтой харьцаж чаддаггүй бол хэдий хөршүүддээ тусламж үзүүлэхэд байгаа бүхнээ зарлагаддаг, эсвэл эцэг эх, гэр бүлийн гишүүдээ сайтар халамжилдаг байсан ч гэсэн, Би чамайг бас л хорон муу хүн, тэр ч байтугай зальжин арга мэхээр дүүрэн нэгэн гэж хэлнэ. Бусадтай эв найртай байдаг, эсвэл хэдхэн сайн үйл хийсэн болохоороо л өөрийгөө Христтэй нийцэлтэй гэж бүү бод. Чи тусархаг санаа зорилгоороо Тэнгэрийн ерөөлийг шударга бус аргаар олж авч чадна гэж бодож байна уу? Хэдхэн сайн үйл хийх нь дуулгавартай байдлыг чинь орлож чадна гэж чи бодож байна уу? Хэдийгээр та нарын нэг нь ч харьцалт, засалтыг хүлээн зөвшөөрч чаддаггүй, бүгдэд чинь Христийн хэвийн хүн чанарыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү санагддаг боловч та нар Бурханд дуулгавартай гэдгээ байнга зарлаж байдаг. Та нарынх шиг ийм итгэл тохирох залхаан цээрлүүлэлтээ хүртэнэ. Хий хоосон төөрөгдөлд автаж, Христийг харахыг хүсэхээ боль, учир нь та нарын биеийн хэмжээ хэтэрхий жаахан, бүр Түүнийг харахад ч тохирохооргүй жаахан. Чи тэрслүү байдлаа бүрэн хаяж, Христтэй эв зохицолтой байж чаддаг болсон мөчид Бурхан чамд аяндаа харагдана. Хэрвээ чи засалт, шүүлт туулахгүйгээр Бурхантай уулзахаар очвол гарцаагүй Бурханыг эсэргүүцэгч болох бөгөөд сүйрэх тавилантай. Хүний уг чанар төрөлхийн Бурханд дайсагнадаг, учир нь бүх хүнийг Сатан хамгийн гүн ялзруулсан. Хэрвээ хүн завхрал дундаасаа гаралгүйгээр Бурхантай харилцахаар оролдвол эндээс ямар ч сайн үр дүн гарахгүй нь тодорхой; үг, үйлдэл нь түүний завхралыг алхам тутамд нь ил болгох нь гарцаагүй бөгөөд Бурхантай харилцах үед тэрслүү байдал нь бүх талаараа илчлэгдэнэ. Хүн өөрийн мэдэлгүйгээр Христийг эсэргүүцэж, Христийг хуурч, Христийг хаядаг; тэр үед хүн нэн аюултай байдалд орох ба энэ нь үргэлжилбэл тэр шийтгүүлэх нэгэн болно.

Хэрвээ Бурхантай харилцах нь ийм аюултай юм бол Бурханаас хол байсан нь дээр гэж зарим хүн бодох байх. Иймэрхүү хүмүүс ер нь юу олж авч чадах юм бэ? Тэд Бурханд үнэнч байж чадах уу? Мэдээж, Бурхантай харилцах нь маш хэцүү, гэхдээ энэ нь хүн завхралаас улбаатай болохоос биш Бурхан хүнтэй харилцах боломжгүйдээ биш юм. Та нар өөрийгөө таньж мэдэх үнэнд илүү их хичээл зүтгэл гаргасан нь дээр. Бурхан Яагаад та нарыг сайшаадаггүй вэ? Та нарын зан чанар яагаад Түүний дургүйг хүргэдэг вэ? Та нарын яриа яагаад Түүний зэвүүцлийг өдөөдөг вэ? Та нар бага зэрэг үнэнч зан гаргамагцаа өөрсдийгөө магтаж, жаахан хувь нэмрийнхээ төлөө шагнал шаарддаг; ялимгүй дуулгавартай байдал харуулах үедээ бусдыг дорд үзэж, аар саархан ажил хийнгүүтээ Бурханд тоомсоргүй ханддаг. Бурханыг гэртээ хүлээж авсныхаа төлөө чи мөнгө, эд зүйлс, магтаал нэхдэг. Ганц хоёр зоос өгөхдөө сэтгэл чинь өвддөг; арвыг өгөх үедээ чи ерөөл хүсэж, чамд бусдаас өөр хандахыг хүсдэг. Та нарынх шиг хүн чанарын талаар ярьж, сонсоход үнэхээр тэвчишгүй. Та нарын үг болон үйлдэлд магтууштай юм байна уу? Үүргээ биелүүлдэг хүмүүс ба биелүүлдэггүй хүмүүс; удирддаг хүмүүс ба дагадаг хүмүүс; Бурханыг гэртээ хүлээн авдаг ба хүлээн авдаггүй хүмүүс; хандивладаг ба хандивладаггүй хүмүүс; номлодог ба үгийг хүлээн авдаг хүмүүс гэх мэт бүх хүмүүс өөрсдийгөө магтдаг. Энэ та нарт инээдтэй санагдахгүй байна уу? Бурханд итгэдэг гэдгээ та нар сайн мэддэг хэдий ч Бурхантай нийцэлтэй байж чаддаггүй. Та нар ямар ч нэмэргүй гэдгээ сайн мэдсээр байж үргэлж л сайрхсаар байдаг. Өөрийгөө хянаж чадахаа больтлоо эрүүл ухаан чинь дордсон юм шиг та нарт санагдахгүй байна уу? Ийм эрүүл ухаантай байж та нар Бурхантай харилцахад яаж тохирох юм бэ? Энэ чухал мөчид та нар өөрсдийнхөө төлөө санаа зовнихгүй байна уу? Та нарын зан чанар аль хэдийн Бурхантай нийцэлтэй байж чадахааргүй хэмжээнд хүртлээ доройтсон. Тийм болохоор та нарын итгэл инээдтэй биш гэж үү? Та нарын итгэл утгагүй биш гэж үү? Чи ирээдүйдээ хэрхэн хандах гэж байна вэ? Чи өөрийн алхах замыг хэрхэн сонгох гэж байна вэ?

ДУУДАГДДАГ НЬ ОЛОН Ч СОНГОГДДОГ НЬ ЦӨӨХӨН

Дагалдагчаа болгохын тулд Би газар дэлхий дээр олон хүнийг хайсан. Энэ бүх дагалдагч дунд тахилчид, удирдагчид, Бурханы хөвгүүд, Бурханы ардууд болон үйлчлэл үзүүлдэг хүмүүс бий. Надад үзүүлдэг үнэнч байдалд нь үндэслэн би тэднийг ангилдаг. Бүгд төрлөөрөө ангилагдах үед, өөрөөр хэлбэл, төрөл бүрийн хүний уг чанар тодорхой болох үед Би хүн төрөлхтнийг аврах зорилгодоо хүрэхийн тулд хүн болгоныг зөв ангилалд нь тоолж, тус бүрийг нь тохирох газарт нь тавина. Би аврахыг хүссэн хүмүүсээ бүлэг бүлгээр нь Өөрийн гэрт дуудаж, дараа нь эцсийн өдрүүдийн ажлаа тэднээр бүгдээр нь хүлээн авхуулдаг. Үүний зэрэгцээ, Би тэднийг төрлөөр нь ангилж, дараа нь үйлдэлд нь үндэслээд хүн бүрийг шагнах юм уу шийтгэдэг. Энэ бол Миний ажлыг бүрдүүлдэг алхмууд юм.

Өнөөдөр Би газар дээр, хүмүүсийн дунд амьдардаг. Хүмүүс Миний ажлыг туулж, Миний айлдварыг хардаг, үүний сацуу Би дагалдагч бүрдээ бүх үнэнийг хайрласнаар тэд Надаас амийг хүлээн авч, улмаар өөрсдийн алхах замыг олж авч болох юм. Учир нь Би бол Бурхан, амь Өгөгч билээ. Олон жилийн ажлын маань туршид хүмүүс ихийг олж авч, ихийг хаясан мөртөө Надад үнэхээр итгэдэггүй гэж Би одоо ч хэлдэг. Учир нь хүмүүс Бурхан гэдгийг минь амаараа л хүлээн зөвшөөрдөг боловч Миний хэлдэг үнэнтэй санал нийлдэггүй, түүнчлэн тэднээс Миний шаарддаг үнэнийг хэрэгжүүлдэггүй. Өөрөөр хэлбэл, хүмүүс үнэний оршин тогтнолыг бус, Бурханы оршин тогтнолыг л хүлээн зөвшөөрдөг; хүмүүс амийн оршин тогтнолыг бус, Бурханы оршин тогтнолыг л хүлээн зөвшөөрдөг; хүмүүс Бурханы мөн чанарыг бус, нэрийг нь л хүлээн зөвшөөрдөг. Би зүтгэлийнх нь төлөө, Намайг мэхлэхийн тулд сайхан сонсогдох үгийг л ашигладгийнх нь төлөө тэднийг жигшдэг; тэдний хэн нь ч Намайг үнэхээр шүтэн мөргөдөггүй. Та нарын үг могойн уруу таталтыг агуулдаг; цаашлаад, тэдгээр нь туйлын ихэрхүү, тэргүүн тэнгэрэлчийн жинхэнэ тунхаглал. Түүнээс гадна, та нарын үйл хэрэг хөсөрдөж, гутамшигтай хэмжээнд хүртлээ салбайж муудсан; хэрээс хэтэрсэн хүсэл, шуналт санаа зорилго чинь сонсож тэвчимгүй байдаг. Та нар бүгд Миний гэрт цагаан эрвээхэй болж, зэвүүцэлтэйгээр хаягдах зүйл болсон. Та нарын хэн нь ч үнэнийг хайрладаггүй; харин ч ерөөгдөж, тэнгэр өөд гарч, Христ газар дэлхий дээр эрх мэдэл эзэмших гайхамшигт үзэгдлийг харахыг хүсдэг. Гэхдээ, маш гүн завхарсан, Бурхан гэж юу болохыг огт мэддэггүй та нар шиг хүн яаж Бурханыг дагахад тохирох билээ гэж та нар ер нь бодож байсан уу? Яаж тэнгэр өөд гарч чадах билээ? Ийм гайхамшигт дүр зургийг буюу урьд өмнө үзэгдээгүй сүр жавхлант дүр зургийг харахад яаж тохирох билээ? Ам чинь хууран мэхлэлт, бузар булай, урван тэрслэлт, биеэ тоосон үгээр дүүрсэн байдаг. Та нар Надад чин сэтгэлийн үг, ариун үг, Миний үгийг туулснаар Надад захирагдсан үгийг хэзээ ч хэлж байгаагүй. Эцэст нь, та нарын итгэл ямар вэ? Та нарын зүрх сэтгэлд ердөө хүсэл, мөнгө л байдаг, оюун ухаанд чинь материаллаг зүйл л байдаг. Өдөр бүр Надаас ямар нэгэн зүйлийг яаж авахаа тооцоолдог. Өдөр бүр Надаас хэчнээн их эд баялаг, хэчнээн их материаллаг зүйл олж авснаа тоолдог. Өдөр бүр, илүү ихийг, илүү өндөр стандартыг эдлэхийн тулд та нар бүр ч их ерөөл өөрсөд дээр чинь бууж ирэхийг хүлээдэг. Хором бүрд та нарын бодол санаанд Би биш, Надаас ирдэг үнэн ч биш, харин та нарын нөхөр, эхнэр, хөвгүүд, охид болон идэж, өмсдөг эд зүйлс чинь байдаг. Та нар яаж бүр их, дээд зэргийн таашаал авч болох талаар л боддог. Гэвч гэдсээ хагартал чихсэн ч та нар цогцос хэвээр бус уу? Гаднаа үнэхээр сайхан хувцсаар өөрсдийгөө гоёсон ч гэсэн, алхаж яваа амьгүй цогцос хэвээр бус уу? Та нар ходоодныхоо төлөө үсээ бууралттал шаргуу ажилладаг ч, Миний ажлын төлөө ширхэг үс ч золиосолдоггүй. Та нар байнга завгүй байж, махан биеийнхээ төлөө, охид хөвгүүдийнхээ төлөө биеэ зүдрээж, тархиа гашилгадаг ч—нэг нь ч Миний хүслийн төлөө санаа зовниж, сэтгэл түгшдэггүй. Та нар Надаас юу олж авна гэж найдсаар байгаа юм бэ?

Ажиллаж байхдаа Би хэзээ ч яардаггүй. Хүмүүс Намайг хэрхэн дагаж байгааг үл харгалзан, ажлаа алхам бүрийн дагуу, төлөвлөгөөнийхөө дагуу хийдэг. Тиймээс Миний эсрэг бүх тэрслэлтийг чинь үл тоон Би тасралтгүй ажилласаар байгаа бөгөөд хэлэх ёстой үгээ үргэлжлүүлэн хэлсээр байдаг. Би Өөрийн үгийг сонсгох гэсэндээ урьдчилан тогтоосон хүмүүсээ Өөрийн гэрт дууддаг. Миний үгэнд захирагдаж, Миний үгийг хүсэн эрмэлздэг бүх хүнийг Би сэнтийнхээ өмнө авчирдаг; Миний үгээс нүүр буруулдаг, Намайг дуулгавартай дагадаггүй, Намайг илт эсэргүүцдэг бүх хүнд эцсийн шийтгэлийг нь хүлээлгэхээр нэг тийш хаядаг. Хүмүүс бүгд завхрал дунд, ёрын муу нэгний гар дор амьдардаг тул Намайг дагадаг хүмүүсээс цөөхөн нь үнэнийг хүсэмжилдэг. Өөрөөр хэлбэл, ихэнх нь Намайг үнэхээр шүтэн мөргөдөггүй; тэд Намайг үнэнтэй хамт шүтэн мөргөдөггүй, харин ов мэхтэй аргаар, завхрал, тэрслэлтээр дамжуулан Миний итгэлийг олж авахаар хичээдэг. Энэ шалтгааны улмаас Би ингэж хэлдэг: Дуудагддаг нь олон ч сонгогддог нь цөөхөн. Дуудагддаг тэр хүмүүс гүнээ завхарсан бөгөөд бүгд нэгэн эрин үед амьдардаг—гэхдээ сонгогддог хүмүүс бол тэдний нэг хэсэг бөгөөд үнэнд итгэж, хүлээн зөвшөөрч, үнэнийг хэрэгжүүлдэг хүмүүс юм. Энэ хүмүүс бол нэг бүхлийн тун өчүүхэн хэсэг бөгөөд тэдний дундаас Би илүү их алдрыг хүлээн авна. Эдгээр үгтэй харьцуулаад сонгогдсон хүмүүсийн дунд байгаа эсэхээ та нар мэдэх үү? Та нарын төгсгөл ямар байх бол?

Миний хэлсэнчлэн, Намайг дагадаг хүмүүс олон боловч Намайг үнэхээр хайрладаг нь цөөхөн. Магадгүй зарим нь “Хэрэв би Таныг хайрлаагүй бол ийм их төлөөс төлөх байсан гэж үү? Хэрэв Таныг хайрлаагүй бол энэ хүртэл дагах байсан гэж үү?” хэмээн хэлнэ. Мэдээж чамд олон шалтгаан байгаа, чиний хайр мэдээж тун их, гэхдээ Намайг гэх хайрын чинь мөн чанар юу вэ? “Хайр” гэдэг нь цэвэр, өө сэвгүй сэтгэл хөдлөлийг хэлдэг бөгөөд хайрлах, мэдрэх, хайхрамжтай байхад зүрх сэтгэлээ ашиглахыг хэлдэг. Хайранд ямар ч болзол, саад бэрхшээл, зай гэж үгүй. Хайранд ямар ч сэжиг, хууран мэхлэлт, заль мэх байдаггүй. Хайранд ямар ч наймаа, бузар бохир үгүй. Хэрэв чи хайрладаг бол мэхлэхгүй, гомдоллохгүй, урвахгүй, тэрслэхгүй, шалж шаардахгүй, эсвэл ямар нэг зүйлийг олж авахаар, тодорхой хэмжээгээр олж авахаар эрэлхийлэхгүй. Хэрэв чи хайрладаг бол өөрийгөө баяртайяа зориулж, бэрхшээлийг баяртайгаар туулж, Надтай нийцэлтэй байж, Миний төлөө өөрт байгаа бүхнээ хаяж, гэр бүл, ирээдүй, залуу нас, гэрлэлтээ орхино. Эс тэгвээс, чиний хайр ердөө ч хайр биш, харин хууран мэхлэлт, урвалт байх болно! Чиний хайр ямар хайр вэ? Жинхэнэ хайр мөн үү? Эсвэл хуурамч уу? Чи хэр ихийг хаясан бэ? Чи хэр ихийг өргөн барьсан бэ? Чамаас Би хэр их хайр хүлээн авсан бэ? Чи мэдэх үү? Зүрх сэтгэл чинь ёрын муу, урвалт, хууран мэхлэлтээр дүүрэн байдаг—ийм байхад та нарын хайрын хэчнээн нь хольцтой байх вэ? Та нар Миний төлөө аль хэдийн хангалттай ихийг орхисон гэж боддог; Намайг гэх хайр чинь аль хэдийн хангалттай гэж боддог. Тэгвэл үг, үйлдэл чинь яагаад үргэлж тэрслүү, хуурамч байдаг юм бэ? Та нар Намайг дагадаг мөртөө

Миний үгийг хүлээн зөвшөөрдөггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг ч дараа нь Намайг хаядаг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг ч Надад итгэдэггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг атлаа Миний оршин тогтнолыг хүлээн зөвшөөрч чаддаггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг мөртөө хэн бэ гэдэгт минь тохируулж Надад ханддаггүй, цаг ямагт Надад хүндрэл учруулдаг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг дагадаг ч бүх хэрэг явдал дээр Намайг хуурч, мэхлэхээр хичээдэг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Надад үйлчилдэг хэрнээ Надаас эмээдэггүй. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар Намайг бүх талаар, бүх зүйл дээр эсэргүүцдэг. Үүнийг хайр гэж үзэх үү? Та нар ихийг зориулсан нь үнэн ч Миний шаарддаг зүйлийг хэзээ ч хэрэгжүүлж байгаагүй. Үүнийг хайр гэж үзэж болох уу? Хянуур тооцоолол нь, Намайг гэх хайрын өчүүхэн ч сэжүүр та нарын дотор байдаггүй гэдгийг харуулдаг. Маш олон жилийн ажил болон энэ бүх үгээр хангасны минь дараа та нар үнэндээ хэр ихийг олж авсан бэ? Өнгөрснөө анхааралтай харвал зохистой бус уу? Би та нарт анхааруулж байна: Миний Өөр лүүгээ дууддаг хүмүүс бол хэзээ ч завхарч байгаагүй хүмүүс биш; харин ч Миний сонгодог хүмүүс бол Намайг үнэхээр хайрладаг хүмүүс билээ. Тиймээс, та нар хэрээс хэтрүүлэхгүйн тулд үг, үйл хэрэгтээ сонор сэрэмжтэй байж, санаа зорилго, бодлоо шалгах ёстой. Эцсийн өдрүүдэд Миний өмнө хайраа өргөн барихын тулд чадах бүхнээ хий, Миний уур хилэн та нараас хэзээ ч холдохгүй байх вий!

ЧИ ХРИСТТЭЙ НИЙЦЭЛТЭЙ БАЙХ ЗАМЫГ ЭРЖ ХАЙХ ЁСТОЙ

Би хүмүүсийн дунд их ажил хийсэн бөгөөд энэ хугацаандаа бас олон ч үг илэрхийлсэн. Эдгээр үг нь бүгд хүний авралын төлөө бөгөөд хүнийг Надтай нийцэлтэй болгохын тулд илэрхийлэгдсэн юм. Гэвч Би газар дээр Өөртэй минь нийцэлтэй байдаг хүн цөөн хэдийг л олж авсан, иймээс Миний үгийг хүн нандигнадаггүй гэж Би хэлнэ, учир нь хүн Надтай нийцдэггүй билээ. Энэ мэтчилэн, Миний хийдэг ажил хүнийг ердөө л Надад шүтэн мөргүүлэхийн төлөө байдаггүй; хамгийн гол нь, хүнийг Надтай нийцэлтэй байж чаддаг болгохын төлөө байдаг. Завхарсан хүн бүхэн Сатаны урхинд амьдардаг, мөн махан биед, аминчхан хүсэлд автан амьдардаг ба тэдний дунд Надтай нийцдэг хүн нэг ч байхгүй. Надтай нийцтэй гэж хэлдэг хүмүүс байдаг ч бүгд тодорхойгүй шүтээн шүтдэг. Хэдийгээр тэд Миний нэрийг ариун хэмээн хүлээн зөвшөөрдөг ч Минийхээс эсрэг замаар явдаг, тэдний үг биеэ тоосон зан, өөртөө итгэлтэй байдлаар дүүрэн байдаг. Учир нь угтаа тэд бүгдээрээ Миний эсрэг байдаг бөгөөд Надтай нийцдэггүй. Өдөр болгон тэд Библиэс Миний ул мөрийг эрж хайж, “тохиромжтой” эшлэлийг тохиолдлоор олоод, түүнийгээ уйгагүй уншиж, судар мэт цээжээр дууддаг. Тэд Надтай хэрхэн нийцэлтэй байхаа мэддэггүй, Надтай дайсагнах гэж юуг хэлдгийг ч мэддэггүй. Зүгээр л бичвэрүүдийг

сохроор уншдаг. Тэд өөрсдийн хэзээ ч хараагүй, харж ч чадахгүй тодорхойгүй Бурханыг Библи дотор хязгаарлачхаад, үүнийгээ завтай цагтаа гаргаж хардаг. Тэд ердөө Библийн хүрээнд л Миний оршин тогтнолд итгэдэг, тэд Намайг Библитэй адилтгадаг; Библи байхгүй бол Би гэж үгүй, Би байхгүй бол Библи гэж үгүй. Тэд Миний оршин тогтнол болон үйлдэлд ямар ч анхаарал хандуулдаггүй, харин оронд нь Бичвэрийн үг нэг бүрд туйлын онцгой анхаарал хандуулдаг бөгөөд Бичвэрт зөгнөөгүй л бол Намайг хийхийг хүссэн зүйлээ огт хийх ёсгүй гэж олонх нь итгэдэг. Тэд Бичвэрт хэтэрхий их ач холбогдол өгдөг. Тэд үг үсгийг хэтэрхий чухалчилж, эцэстээ бүр хэлсэн үг бүрийг минь дэнсэлж, Намайг яллахад Библийн эшлэлүүдийг ашигладаг гэж хэлж болно. Тэдний эрж хайдаг зүйл нь Надтай нийцэлтэй байх зам юм уу үнэнтэй нийцэлтэй байх зам бус, харин Библийн үгтэй нийцэлтэй байх зам бөгөөд Библитэй нийцэхгүй л бол бүгдийг нь, огт ялгалгүйгээр Миний ажил биш гэж тэд итгэдэг. Ийм хүмүүс фарисайчуудын ачлалт үр удам биш гэж үү? Иудейн фарисайчууд Есүсийг яллахын тулд Мосегийн хуулийг ашигласан. Тэр үед тэд Есүстэй нийцэлтэй байхыг эрж хайгаагүй, харин хуулийг үг үсэггүй хичээнгүйлэн дагаж, бүр Есүст Хуучин Гэрээний хуулийг дагаагүй, мөн Мессиа биш хэмээн ял оноогоод, эцэст нь гэм зэмгүй Есүсийг загалмайд цовдолсон. Тэд ямар мөн чанартай байсан бэ? Тэд үнэнтэй нийцэлтэй байх замыг хайгаагүй юм биш үү? Тэд Миний хүсэл болон Миний ажлын үе шат, арга барилын аль алиныг нь хайхардаггүй байсан мөртөө Бичвэрийн үг нэг бүрээр хэнээрхдэг байсан. Тэд үнэнийг эрж хайдаг биш, харин үгтэй салахгүй зууралддаг хүмүүс байсан; тэд Бурханд итгэдэг биш, харин Библид итгэдэг хүмүүс байсан юм. Үнэн хэрэгтээ тэд Библийн хоточ нохой байсан. Библийн ашиг сонирхлыг хамгаалж, Библийн нэр төрийг хадгалж, Библийн алдар хүндийг хамгаалахын тулд тэд эцэст нь өршөөнгүй Есүсийг загалмайд цовдлохдоо тулсан. Тэд ердөө Библийг хамгаалахын төлөө, хүмүүсийн зүрх сэтгэл дэх Библийн үг нэг бүрийн байр суурийг хадгалахын төлөө л үүнийг хийсэн юм. Иймээс тэд Бичвэрийн номлолыг мөрддөггүй байсан Есүсийг үхлийн ялаар яллахын тулд өөрсдийн ирээдүй болон нүглийн тахилыг хаяхыг илүүд үзсэн. Тэд Бичвэрийн үг нэг бүрийн боол байгаагүй гэж үү?

Тэгвэл өнөөдрийн хүмүүс ямар вэ? Христ үнэнийг илэрхийлэхээр ирчхээд байхад тэд тэнгэрт орж, нигүүлсэл хүртэхийн тулд Христийг энэ ертөнцөөс хөөн зайлуулахыг илүүд үзнэ. Библийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд үнэний ирэлтийг бүрмөсөн үгүйсгэхийг илүүд үзэж, Библийн мөнх оршин тогтнолыг баталгаажуулахын тулд махбодод эргэн ирсэн Христийг загалмайд дахин цовдлохыг илүүд үзнэ. Зүрх сэтгэл нь ийм хорлонтой, Надад тийм их дайсагнадаг уг чанартай байж хүн яаж Миний авралыг хүртэж чадах юм бэ? Би хүмүүсийн дунд амьдардаг атал хүн Миний оршин байгааг мэддэггүй. Өөр дээр нь гэрлээ тусгах үед ч хүн Миний оршин байгааг мэдэхгүй хэвээр байдаг. Намайг уур хилэнгээ өөр дээр нь буулгах үед хүн Миний оршин тогтнолыг бүр ч эрс үгүйсгэдэг. Хүн үг үсэгтэй, Библитэй нийцэхээр эрэлхийлдэг, гэхдээ үнэнтэй нийцэлтэй байх замыг хайхаар нэг ч хүн Миний өмнө

ирдэггүй. Хүн тэнгэр дэх Намайг хүндэлж, тэнгэр дэх Миний оршин тогтнолд онцгой анхаарал хандуулдаг атлаа хүмүүсийн дунд амьдардаг Би бол ердөө л тун өчүүхэн нэгэн болохоор махбод дахь Миний талаар хэн ч санаа тавьдаггүй. Библийн үгтэй л, тодорхойгүй Бурхантай л нийцэлтэй байхыг эрж хайдаг хүмүүс Надад өөдгүй дорд харагддаг. Учир нь тэдний шүтэн мөргөдөг зүйл нь үхмэл үг, бас өөрсдөд нь тоо томшгүй их эд баялаг өгөх чадвартай Бурхан юм. Тэдний шүтэн мөргөдөг зүйл нь оршин байдаггүй агаад хүний эрхээр байдаг Бурхан юм. Тэгвэл ийм хүмүүс Надаас юу олж авч чадах юм бэ? Хүн ердөө л үгээр илэрхийлэхийн аргагүй дорд юм. Миний эсрэг байж, Надаас хязгааргүй ихийг шаарддаг, үнэнийг огт хайрладаггүй, Миний эсрэг тэрсэлдэг тэр хүмүүс яаж Надтай нийцэлтэй байж чадах юм бэ?

Миний эсрэг байдаг хүмүүс бол Надтай нийцэлгүй хүмүүс юм. Мөн үнэнийг хайрладаггүй хүмүүс ч Надтай нийцэлгүй хүмүүс. Миний эсрэг тэрсэлдэг хүмүүс бол бүр ч Миний эсрэг байдаг, Надтай нийцдэггүй хүмүүс билээ. Надтай нийцэлгүй бүх хүнийг Би муу ёрын нэгний гарт өгч, муу ёрын нэгний ялзралд орхиж, хорон муу үйлийг нь илчлэхийн тулд зөнгөөр нь орхиж, эцэст нь муу ёрын нэгэнд залгиулахаар шилжүүлнэ. Хэчнээн хүн Намайг шүтэн мөргөдөг нь Надад хамаагүй, өөрөөр хэлбэл, хэчнээн хүн Надад итгэдэг нь хамаагүй. Хэчнээн хүн Надтай нийцэлтэй вэ гэдэг л санааг минь чилээдэг ганц зүйл юм. Учир нь Надтай нийцэлгүй бүх хүн бол Надаас урвадаг муу ёрын хүмүүс билээ; тэд Миний дайсан бөгөөд дайснуудаа Би Өөрийн гэрт “тахихгүй.” Надтай нийцэлтэй хүмүүс Миний гэрт үүрд Надад үйлчилнэ, харин Надтай дайсагнадаг хүмүүс Миний шийтгэлийг үүрд амсана. Библийн үгийг л анхаарч, үнэний талаар юм уу Миний мөрийг эрж хайх талаар хайхрамжгүй ханддаг хүмүүс бүгд Миний эсрэг байдаг, учир нь тэд Библийн дагуу Намайг хязгаарлаж, Библийн дотор Намайг хорьдог, тэд ийм байдлаар үйлдэх нь миний хувьд туйлын их доромжлол юм. Ийм хүмүүс яаж Миний өмнө ирж чадах юм бэ? Тэд Миний үйл хэрэгт, Миний хүсэлд, эсвэл үнэнд ямар ч анхаарал хандуулдаггүй, харин ч хүнийг үхүүлдэг үгэнд донтдог. Тийм хүмүүс яаж Надтай нийцэлтэй байж чадах юм бэ?

Би маш олон үг илэрхийлж, хүсэл болон зан чанараа ч бас илэрхийлсэн, гэсэн атал хүмүүс одоо ч Намайг мэдэж, Надад итгэх чадваргүй л байна. Эсвэл, тэд одоо ч Намайг дуулгавартай дагаж чаддаггүй гэж хэлж болно. Библид амьдрагсад, хууль дунд амьдрагсад, загалмай дээр амьдрагсад, дүрэм журмын дагуу амьдрагсад, өнөөдөр Миний хийдэг ажлын дунд амьдрагсад дундаас хэн нь Надтай нийцэлтэй вэ? Та нар ерөөл, шагнал хүртэх тухай л боддогоос биш, Надтай хэрхэн нийцэлтэй байх, Намайг эсэргүүцдэг Нэгэн болохоос хэрхэн сэргийлэх талаар хэзээ ч бодолцож үзээгүй. Би та нарт үнэхээр урам хугарч байна, учир нь та нарт Би маш ихийг өгөөд, хариуд нь та нараас өчүүхэн багыг олж авсан. Та нарын заль мэх, их зан, шунал, тансаглах хүсэл, урвалт, дуулгаваргүй байдал—эдгээрийн аль нь Надад анзаарагдалгүй өнгөрөх юм бэ? Та нар Намайг аргацааж, Намайг хуурч, Намайг гутааж, Намайг аргалж, тахилын төлөө Намайг хяхаж, сүрдүүлдэг—ийм

хорон үйл яаж Миний шийтгэлээс мултарч чадах юм бэ? Та нарын эдгээр муу үйл бол Миний дайсан гэдгийн чинь нотолгоо, бас Надтай үл нийцдэгийн чинь нотолгоо юм. Та нар дор бүрнээ өөрсдийгөө Надтай маш нийцэлтэй гэж итгэдэг, гэхдээ тийм байсан юм бол эдгээр маргашгүй нотлох баримт тэгээд хэнд нь хамаарах юм бэ? Та нар өөрсдийгөө Надад туйлын чин үнэнч, итгэмжит гэдэгт итгэдэг. Та нар өөрсдийгөө маш сайхан сэтгэлтэй, өр нимгэн бөгөөд Надад маш ихийг зориулсан гэж боддог. Бас Миний төлөө хангалттай ихийг хийсэн гэж боддог. Гэвч та нар эдгээр итгэлээ өөрсдийнхөө зан авиртай жишиж үзсэн үү? Та нар бол ихэд биеэ тоосон, ихээхэн шуналтай, ихээхэн хайхрамжгүй гэж Би хэлнэ; та нарын Намайг хуурдаг арга заль нэлээд сүйхээтэй, бас та нарт жигшүүрт санаа зорилго болон арга барил их бий. Та нарын үнэнч байдал үнэхээр шалихгүй, чин сэтгэл чинь дэндүү өчүүхэн, мөс чанар чинь бүр ч дутмаг. Зүрх сэтгэл чинь дэндүү хорлонтой байдаг бөгөөд хэнийг ч, цаашлаад Намайг ч хэлтрүүлдэггүй. Та нар хүүхдүүдийнхээ төлөө, нөхрийнхөө төлөө, эсвэл өөрийнхөө бүрэн бүтэн байдлын төлөө Намайг гэртээ оруулдаггүй. Надад санаа тавихын оронд та нар өөрсдийнхөө гэр бүл, үр хүүхэд, байр суурь, ирээдүй болоод өөрсдийн жаргал цэнгэлд санаа тавьдаг. Та нар үг хэлж, үйлдэл хийх үедээ хэзээ Миний талаар бодож байсан юм бэ? Тэсгэм хүйтэн өдрүүдэд ухаан бодол чинь үр хүүхэд, нөхөр, эхнэр, эцэг эх рүүгээ л чиглэдэг. Аагим халуун өдрүүдэд ч гэсэн та нарын бодол санаанд Намайг гэх орон зай байдаггүй. Үүргээ биелүүлэхдээ чи хувийн ашиг сонирхол, аюулгүй байдал, гэр бүлийн гишүүдээ л боддог. Чи Миний төлөө гэх юм юу хийсэн юм бэ? Хэзээ чи Миний талаар бодож байсан бэ? Хэзээ чи Миний төлөө, бас Миний ажлын төлөө ямар ч үнээр хамаагүй өөрийгөө зориулж байсан юм бэ? Надтай нийцэлтэй гэдгийн чинь нотолгоо хаана байна вэ? Надад үнэнч гэдгийн чинь бодит байдал хаана байна вэ? Дуулгавартай байдлын чинь бодит байдал хаана байна вэ? Санаа зорилго чинь хэзээ Надаас ерөөл олж авахын төлөө байгаагүй билээ? Та нар бүгд Намайг хуурч, мэхлэн, үнэнээр тоглоом хийж, үнэний оршин байгааг нуун, үнэний мөн чанараас урвадаг. Надтай ингэж дайсагнасны чинь төлөө та нарыг ирээдүйд юу хүлээж байгаа вэ? Та нар ердөө л тодорхойгүй Бурхантай нийцэлтэй байхыг болон тодорхойгүй итгэлийг эрж хайдаг, гэсэн ч та нар Христтэй нийцэлтэй биш. Ийм хорлонт үйл чинь хорон муу хүмүүст тохирсон яг тэр шийтгэлийг хүртэхгүй гэж үү? Тэр үед та нар Христтэй нийцэлгүй хэн ч уур хилэнгийн өдрөөс зугтаж чадахгүй гэдгийг ухаарч, Христтэй дайсагнадаг хүмүүст ямар төрлийн залхаан цээрлүүлэлт ирэхийг мэдэх болно. Тэр өдөр ирэх үед Бурханд итгэснийхээ төлөө ерөөгдөж, тэнгэрт орох мөрөөдөл чинь нуран унана. Харин Христтэй нийцэлтэй хүмүүсийн хувьд бол өөр хэрэг. Тэд маш ихийг алдаж, олон бэрхшээл туулсан ч хүн төрөлхтөнд өгсөн бүх өв залгамжлалыг минь хүлээн авах болно. Би л зөвт Бурхан бөгөөд Би л хүн төрөлхтнийг үзэсгэлэнтэй сайхан хүрэх газар луу аваачих чадвартай гэдгийг та нар эцэст нь ойлгоно.

ЧИ БУРХАНЫ ЖИНХЭНЭ ИТГЭГЧ МӨН ҮҮ?

Чи Бурханд итгэх итгэлийн замаар нэг, хоёроос дээш жил алхаж, энэ жилүүдэд амьдралдаа их зовлон зүдүүр амссан байж магадгүй; эсвэл магадгүй чи их зовлон зүдүүр амсалгүй, харин ч нигүүлслийг ихээр хүртсэн байж болох юм. Мөн чи зовлон, нигүүлсэл хоёрын аль алийг нь үзэлгүйгээр харин эгэл жирийн амьдралаар амьдарсан байж ч болно. Ямартай ч, чи Бурханы дагагч хэвээр тул Бурханыг дагах тухай сэдвээр нөхөрлөцгөөе. Гэвч Бурханы үг Түүнийг хүлээн зөвшөөрч, дагадаг хүмүүст чиглэдэг болохоос Түүнийг хүлээн зөвшөөрдөг ч байсан, үгүй ч байсан бүх хүнд чиглэдэггүй гэдгийг Би энэ үгсийг уншдаг бүхэнд сануулах ёстой. Хэрвээ чи Бурхан нийтэд, дэлхий дээрх бүх хүнд хандан үг хэлдэг гэж боддог бол Бурханы үг чамд ямар ч нөлөө үзүүлэхгүй. Тиймээс чи энэ бүх үгийг зүрх сэтгэлдээ санаж, өөрийгөө байнга тэдгээрийн гадна тавихгүй байх хэрэгтэй. Ямар ч байсан, бидний гэрт юу болж байгаа талаар ярилцацгаая.

Та бүхэн одоо Бурханд итгэхийн жинхэнэ утга учрыг ойлгох хэрэгтэй. Өмнө нь Миний ярьсан Бурханд итгэхийн утга учир нь та нарын эерэг оролттой холбоотой байсан. Өнөөдөр бол өөр: Өнөөдөр, Би Бурханд итгэх итгэлийн чинь мөн чанарыг задлан шинжилмээр байна. Мэдээж, энэ нь та нарыг сөрөг талаас залж чиглүүлж буй хэрэг юм; Намайг тэгээгүй бол та нар өөрсдийн үнэн нүүр царайг үүрд мэдэлгүй, сүсэг бишрэлтэй, үнэнч байдлаараа үүрд сайрхах байсан. Хэрвээ Би зүрх сэтгэлийн гүн дэх муу муухайг чинь ил болгоогүй бол та нар дор бүрнээ толгой дээрээ титэм зүүгээд, бүх алдрыг өөрсдөдөө авч үлдэх байсан гэж хэлэхэд буруудахгүй. Биеэ тоосон, ихэрхүү уг чанар чинь өөрсдийн мөс чанараас урваж, Христийг эсэргүүцэн тэрсэлж, муу муухайгаа илчлэхэд хүргэснээр та нарын санаа зорилго, үзэл, хэрээс хэтэрсэн хүсэл, шуналаар дүүрэн нүдийг гэрэлд ил болгодог. Гэсэн ч, та нар Христийн ажлыг гэсэн насан туршийн хүсэл тэмүүллийнхээ талаар үргэлжлүүлэн чалчиж, Христийн аль эрт хэлсэн үнэнийг ахин дахин давтдаг. Энэ бол та нарын “итгэл”—“өө сэвгүй итгэл” юм. Би бүхий л хугацаанд хүнд хатуу чанд стандарт тавьж ирсэн. Хэрвээ чи санаархал болзолтойгоор үнэнч байдаг бол чиний тэр үнэнч байдал гэх зүйл Надад хэрэггүй, учир нь санаархлаараа Намайг хуурч, болзлоороо Намайг сүрдүүлдэг хүмүүсийг Би жигшин зэвүүцдэг. Би хүнийг Надад туйлын үнэнч байж, итгэл гэдэг ганц үгийн төлөө, үүнийг батлахын тулд бүх зүйлийг хийгээсэй л гэж хүсдэг. Намайг хөөргөх гэж зулгуйдахыг чинь Би үзэн яддаг, учир нь Би та нарт үргэлж чин сэтгэлээсээ ханддаг, тиймээс та нарыг ч бас Надад жинхэнэ итгэлээр хандаасай гэж хүсдэг. Итгэлийн тухайд гэвэл, өөрсдөд нь итгэл байгаа учраас Бурханыг дагадаг, эс бөгөөс ийм зовлон зүдүүрийг тэвчихгүй байсан гэж олон хүн бодож байж болох юм. Тиймээс Би чамаас үүнийг асууя: Чи Бурханы оршин тогтнолд итгэдэг юм бол яагаад Түүнийг хүндэтгэдэггүй юм бэ? Чи Бурханы оршин тогтнолд итгэдэг юм бол яагаад чамд Түүнээс жаахан ч гэсэн айх зүрх сэтгэл байдаггүй юм бэ? Чи Христийг бие махбодтой болсон Бурхан гэж хүлээн

зөвшөөрдөг хэр нь Түүнийг яагаад басамжилдаг юм бэ? Чи яагаад Түүнд хүндлэлгүй ханддаг юм бэ? Чи яагаад Түүнийг ил тодоор шүүмжилдэг юм бэ? Чи яагаад үргэлж Түүний хөдөлгөөнийг тагнадаг юм бэ? Чи яагаад Түүний зохицуулалтад захирагддаггүй юм бэ? Чи яагаад Түүний үгийн дагуу үйлддэггүй юм бэ? Яагаад Түүнийг сүрдүүлж, тахилыг нь дээрэмдэхийг хичээдэг юм бэ? Чи яагаад Христийн байр сууриас үг хэлдэг юм бэ? Чи яагаад Түүний ажил болон үг зөв эсэхийг шүүдэг юм бэ? Яагаад ар хударгаар нь Түүнийг зүхэж зүрхэлдэг юм бэ? Энэ бүхэн нь та нарын итгэл юм гэж үү?

Үг яриа, зан авирт чинь Христэд үл итгэдэг элементүүд чинь харагддаг. Хийдэг бүхний чинь сэдэл, зорилгод үл итгэл шингэсэн байдаг. Та нарын харцны золбоо хүртэл Христэд үл итгэх байдлыг агуулдаг. Та нар дор бүрнээ, хором бүрд үл итгэлийн элементийг өвөрлөж байдаг гэж хэлж болно. Энэ нь бие махбодтой болсон Бурханд үл итгэх байдал биеэр чинь гүйж буй цусанд нэвт шингэсэн учраас та нар хором мөч бүрд Христээс урвах аюулд байдаг гэсэн үг юм. Тиймээс, Бурханд итгэх замд үлдээдэг мөр чинь жинхэнэ биш гэж Би хэлдэг; Бурханд итгэх зам дээр алхахдаа чи хөлөө газарт бат тавьдаггүй—чи зүгээр л хэлбэр төдий хийж байна. Та нар Христийн үгэнд хэзээ ч бүрэн итгэдэггүй бөгөөд даруйхан хэрэгжүүлж чаддаггүй. Та нарын Христэд итгэдэггүйн шалтгаан энэ юм. Үргэлж Түүний талаар үзэлтэй байдаг чинь Түүнд итгэдэггүйн бас нэг шалтгаан мөн. Христийн ажлын талаар үргэлж эргэлзэх, Христийн үгийг чихнийхээ хажуугаар өнгөрөөх, Христийн хийсэн ямар ч ажлын талаар санаа бодол өвөрлөж, энэ ажлыг зөвөөр ойлгож чадахгүй байх, яаж ч тайлбарлалаа гэсэн үзлээ хаяхад хэцүү байх зэрэг нь бүгдээрээ та нарын зүрх сэтгэлд холилдсон үл итгэлийн элементүүд юм. Та нар хэзээ ч ард хоцролгүй, Христийн ажлыг дагадаг хэдий ч зүрх сэтгэлд чинь хэт их тэрслүү байдал холилдсон байна. Энэхүү тэрслүү байдал нь Бурханд итгэх итгэлд чинь байгаа хир буртаг юм. Та нар тэгж бодохгүй байж магад, гэхдээ чи санаа зорилгоо энэ дотроос танин мэдэж чадахгүй бол мөхөх хүмүүсийн дунд байх нь гарцаагүй. Учир нь Бурхан Өөрт нь эргэлздэг хүмүүсийг бус, харин үнэхээр итгэдэг хүмүүсийг л төгс болгодог бөгөөд Түүнийг Бурхан гэж хэзээ ч итгээгүй хэр нь Түүнийг дурамжхан дагадаг хүмүүсийг бол бүр ч төгс болгохгүй.

Зарим хүн шүүлтэд байтугай, үнэнд ч баясдаггүй. Харин тэд эрх мэдэл, эд баялагт баясдаг; ийм хүмүүсийг эрх мэдэл эрэлхийлэгчид гэж нэрлэдэг. Тэд дэлхий дээрх нөлөө бүхий урсгал, шашны сургуулиас ирсэн пастор, багш нарыг л эрж хайдаг. Тэд үнэний замыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч, хагас дутуу л итгэж байдаг; тэд зүрх сэтгэл, оюун санаагаа бүрэн зориулах чадваргүй, амаараа Бурханы төлөө өөрсдийгөө зарлагадах тухай ярих боловч харц нь агуу пастор, багш нар дээр төвлөрч, Христийг зэрвэс ч хардаггүй. Зүрх сэтгэл нь нэр төр, эд баялаг, яруу алдрыг анхаардаг. Ийм өчүүхэн хүн тийм олон хүнийг байлдан дагуулах чадвартай, ийм эгэл жирийн хүн, хүнийг төгс болгох чадвартай байх боломжгүй гэж тэд боддог. Тоос тортог, өтөг бууц дундах тэдгээр хэн ч биш хүн Бурханы сонгосон хүмүүс байх

боломжгүй гэж тэд боддог. Хэрвээ ийм хүмүүсийг Бурхан авардаг байсан бол тэнгэр газар орвонгоороо эргэж, бүх хүн элгээ хөштөл инээх байсан гэж тэд үздэг. Хэрэв Бурхан энэхүү хэн ч биш хүмүүсийг төгс болгохоор сонгох юм бол өнөөх агуу хүмүүс Бурхан Өөрөө болох байсан гэж тэд боддог. Тэдний харах өнцгийг үл итгэл сэвтүүлсэн байдаг; тэд үл итгээд ч зогсохгүй, зүгээр л утгагүй араатнууд юм. Учир нь тэд байр суурь, нэр хүнд, эрх мэдлийг л үнэлдэг, зөвхөн том бүлэглэл, урсгалуудыг л хүндэтгэдэг. Тэд Христээр удирдуулж байгаа хүмүүсийг огтхон ч тоодоггүй; тэд ердөө л Христ, үнэн, амиас нүүр буруулсан урвагчид юм.

Чи Христийн даруу занг бус, харин эрхэм хүндтэй байр суурь бүхий тэр хуурамч хоньчдыг л гайхан биширдэг. Чи Христийн хайр татам байдал, мэргэн ухааныг биш, харин бузар булай ертөнцөд хөлбөрдөг тэдгээр самуун явдалтныг эрхэмлэн хайрладаг. Чи толгой хоргодох газаргүй Христийн шаналлыг шоолж, харин тахил агнаж, цадиггүй амьдардаг тэдгээр үхдэлийг гайхан биширдэг. Чи Христтэй хамт зовохыг хүсдэггүй, харин махан бие, үгээр л чамайг тэтгэж, хянаж байдаг тэр бодлогогүй антихристүүдийн тэвэрт дуртайяа очдог. Одоо ч гэсэн зүрх сэтгэл чинь тэдэн рүү, тэдний нэр хүнд, байр суурь, нөлөө рүү хандсан хэвээр байна. Гэсэн ч, Христийн ажил хүлээн авахад хэцүү санагдаж, чи үүнийг хүлээн авахыг хүсдэггүй. Иймээс Христийг хүлээн зөвшөөрөх итгэл чамд байхгүй гэж Би хэлдэг. Чамд өөр ямар ч сонголт байхгүй байсан учраас л өнөөг хүртэл Түүнийг дагасан. Зүрх сэтгэлд чинь хэд хэдэн сүрлэг дүр төрх үүрд сүндэрлэж байгаа; чи тэдний үг, үйл бүрийг, мөн нөлөө бүхий үг, гарыг нь ч мартаж чаддаггүй. Та нарын зүрх сэтгэлд тэд үүрд дээдийн дээд, үүрд баатрууд хэвээрээ байдаг. Харин өнөөдрийн Христийн хувьд тийм биш. Чиний зүрх сэтгэлд Тэр үүрд ялихгүй хэвээрээ, үүрд хүндэтгэл хүлээх зохисгүй хэвээрээ. Учир нь Тэр хэтэрхий эгэл, хэтэрхий бага нөлөөтэй, ямар ч сүрлэг байдалгүй.

Ямар ч байсан, үнэнийг үнэлдэггүй бүх хүн бол үл итгэгчид, үнэнээс урвагчид юм гэж Би хэлдэг. Ийм хүмүүс хэзээ ч Христийн сайшаалыг хүртэхгүй. Чиний дотор хэр их үл итгэл байгааг, мөн Христээс хэр их урваж байгаагаа чи одоо олж тогтоов уу? Би чамд ингэж захья: Чи үнэний замыг сонгосон тул өөрийгөө үнэн сэтгэлээсээ зориулах хэрэгтэй; хоёрдмол сэтгэлээр, хайнга бүү бай. Бурхан бол дэлхий ертөнцөд ч, хэн нэг хүнд ч биш, харин Түүнд үнэхээр итгэж, Түүнийг шүтэн мөргөж, Түүнд үнэнч агаад итгэлтэй байдаг бүх хүнд харьяалагддаг гэдгийг чи ойлгох ёстой.

Өнөөдөр та нарын дотор үл итгэх байдал их байсаар байна. Өөрсдийнхөө дотогшоо сайтар өнгийвөл та нар хариултаа гарцаагүй олно. Чи жинхэнэ хариултыг олох үедээ өөрийгөө Бурханд итгэгч биш, харин ч Түүнийг хуурч, доромжилж, Түүнээс урвадаг, Түүнд үнэнч бус нэгэн гэдгээ хүлээн зөвшөөрөх болно. Тэгээд Христ бол хүн биш, Бурхан гэдгийг ойлгоно. Ийм өдөр ирэхэд чи Христийг хүндэтгэж, Түүнээс айж, Түүнийг үнэхээр хайрлана. Одоогоор та нарын зүрх сэтгэлийн ердөө гучин хувийг итгэл дүүргэдэг бол далан хувийг нь эргэлзээ дүүргэдэг. Христийн хийдэг, хэлдэг бүхнээс болж та нарт Түүний тухай үзэл, санаа бодол, Түүнд огт итгэдэггүйгээс чинь урган гарсан үзэл, санаа бодол бий болдог. Та нар тэнгэр дэх

нүдэнд үл үзэгдэх Бурханыг л гайхан биширч, айж эмээдэг бөгөөд газар дээр амьдарч байгаа Христийг үл хайхардаг. Энэ чинь мөн л та нарын үл итгэл бус уу? Та нар өнгөрсөн үед ажил хийсэн Бурханыг л хүсэмжлэхээс биш, өнөөдрийн Христтэй нүүр тулдаггүй. Энэ бүхэн бол та нарын зүрх сэтгэлд үүрд холилдсон “итгэл”, өнөөдрийн Христэд итгэдэггүй тэр итгэл юм. Би та нарыг огтхон ч дутуу үнэлж байгаа юм биш, учир нь та нарын дотор хэт их үл итгэл байдаг, та нарт ариун бус, задлан шинжлэх ёстой зүйл хэтэрхий олон байдаг. Эдгээр ариун бус зүйл нь та нарт итгэл огт байхгүйн тэмдэг юм; эдгээр нь Христээс татгалзсаны чинь тэмдэг бөгөөд та нарыг Христээс урвагч гэж тамгалдаг. Эдгээр нь Христийн тухай мэдлэгийн чинь хаалт, Христээр авхуулахад чинь саад болдог саад, Христтэй нийцэлтэй байхад чинь саад хийдэг бартаа, мөн Христ та нарыг сайшаадаггүйн нотолгоо билээ. Одоо бол та нарын амьдралынхаа бүх талыг шинжлэх цаг! Ингэх нь та нарт бүхий л талаар ашиг тустай байх болно!

ХРИСТ ШҮҮЛТИЙН АЖЛЫГ ҮНЭНЭЭР ХИЙДЭГ

Эцсийн өдрүүдийн ажил бол бүгдийг төрлөөр нь ялгаж, Бурханы удирдлагын төлөвлөгөөг дуусгах ажил юм, учир нь цаг ойртож, Бурханы өдөр ирсэн. Бурхан хаанчлалд нь орсон бүх хүнийг буюу Өөрт нь эцсээ хүртэл үнэнч байсан бүх хүнийг Бурханы Өөрийн эрин үе рүү аваачдаг. Гэвч Бурханы Өөрийн эрин үе ирэх хүртэл Бурханы хийх ажил гэвэл хүний үйл хэргийг ажиглах болон хүний амьдралын талаар лавлах бус, харин тэрслүү байдлыг нь шүүх явдал юм, учир нь Бурхан Өөрийн сэнтийн өмнө ирсэн бүх хүнийг ариусгана. Өнөөдрийг хүртэл Бурханы мөрийг дагасан бүх хүн бол Бурханы сэнтийн өмнө очсон хүмүүс юм, иймээс Бурханы ажлыг эцсийн үе шатанд нь хүлээн авах хүн нэг бүр Бурханы ариусгалтын бай мөн. Өөрөөр хэлбэл, Бурханы эцсийн үе шатандаа яваа ажлыг хүлээн авдаг хүн бүхэн Бурханы шүүлтийн бай билээ.

Өнгөрсөн цаг үед яригдаж байсан Бурханы гэрээс эхлэх шүүлтийн тухайд, эдгээр үгэн дэх “шүүлт” гэдгээр эцсийн өдрүүдэд сэнтийнх нь өмнө ирсэн хүмүүс дээр Бурханы өнөөдөр хийдэг шүүлтийг хэлдэг. Эцсийн өдөр ирсэн үед Бурхан тэнгэрт том ширээ засаж, дээр нь цагаан бүтээлэг дэвсээд, дараа нь бүх хүнийг газарт өвдөг сөгдүүлж, Өөрөө агуу сэнтийд суунгаа хүн бүрийн нүглийг илчилж, үүгээрээ тэднийг тэнгэрт гаргах уу, гал болон хүхэрт нуурт унагах уу гэдгийг тогтоодог гэж ер бусаар төсөөлөн боддог хүмүүс байж магад. Хүний төсөөлөл ямар ч байлаа гэсэн, Бурханы ажлын мөн чанарыг өөрчилж чадахгүй. Хүний төсөөлөл гэдэг хүний харсан, сонссон зүйлийг нийлүүлж, нэгтгэсэн, хүний тархинаас гардаг, санаа бодлынх нь бүтээл төдий юм. Иймд Би, хүний төсөөлөл хэчнээн гайхамшигтай байлаа ч зураглал төдийхнөөс хэтрэхгүй ба Бурханы ажлын төлөвлөгөөг орлож чадахгүй гэж хэлдэг. Эцсийн эцэст, хүнийг Сатан завхруулсан тул хүн яаж Бурханы

бодлыг ойлгож чадах юм бэ? Хүн Бурханы шүүлтийн ажлыг маш гайхамшигтай байна гэж боддог. Бурхан Өөрөө шүүлтийн ажил хийж байгаа учраас хамгаас өргөн цар хүрээтэй, эгэл хүмүүст ойлгомжгүй байх ёстой, энэ нь тэнгэр даяар цуурайтаж, газрыг доргиох ёстой гэж боддог; эс бөгөөс энэ яаж Бурханы хийсэн шүүлтийн ажил байж чадах юм бэ? Энэ нь шүүлтийн ажил болохоор Бурхан ажиллахдаа маш сүрлэг, сүр жавхлантай байх ёстой ба шүүгдэж байгаа хүмүүс цурхиран уйлж, өвдөг дээрээ сөхрөн өршөөл хүсэж байх ёстой гэж тэр боддог. Ийм дүр зураг гайхамшигтай, үнэхээр сэтгэл хөдлөм байх нь гарцаагүй… Хүн бүр Бурханы шүүлтийн ажлыг ер бусын гайхалтай гэж төсөөлдөг. Гэвч Бурхан хүмүүсийн дунд шүүлтийн ажлаа аль хэдийн эхэлчхээд байх үед ч чи үхсэн юм шиг унтсаар үлдсэн гэдгээ мэдэх үү? Чамайг Бурханы шүүлтийн ажил албан ёсоор эхэлж байна гэж бодох үед Бурхан аль хэдийн газар тэнгэрийг шинээр бүтээчихсэн байх болно гэдгийг мэдэх үү? Магадгүй тэр үед чи амьдралын утга учрыг дөнгөж ойлгосон байх боловч бөх унтсаар л буй чамайг Бурханы өршөөлгүй шийтгэлийн ажил там руу аваачих болно. Тэр үед л чи Бурханы шүүлтийн ажил аль хэдийн дууссаныг гэнэт ухаарна.

Тэдгээр ой гутам, жигшүүртэй сэдвийн талаар ярьж, үнэт цагаа үрэхээ больцгооё. Харин шүүлт гэж юу болох тухай ярилцацгаая. “Шүүлт” гэдэг үгийг дурдах үед чи Еховагийн бүх газар оронд хэлсэн үг болон Есүсийн фарисайчуудад хэлсэн зэмлэлийн үгийн тухай бодох болно. Эдгээр үг хэдийгээр хатуу ч гэлээ хүнийг шүүх Бурханы шүүлт байгаагүй, ердөө л өөр өөр орчинд буюу өөр өөр нөхцөлд Бурханы хэлсэн үг байсан юм. Эдгээр үг нь эцсийн өдрүүдэд хүнийг шүүхдээ Христийн хэлдэг үгтэй адилгүй. Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг, хүн Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдогтой холбогдуулан хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авдаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг

шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ. Хэрэв чи эдгээр үнэнийг чухалчлан авч үздэггүй, эдгээр үнэнээс хэрхэн зайлсхийх вэ, эсвэл тэдгээртэй хамааралгүй шинэ замыг хэрхэн олох вэ гэж л үргэлж боддог бол Би чамайг хүнд нүгэлтэн гэж хэлнэ. Чи Бурханд итгэдэг атлаа үнэнийг болон Бурханы хүслийг эрж хайдаггүй, мөн чамайг Бурханд ойртуулдаг замыг ч хайрладаггүй бол Би чамайг, шүүлтээс булталхаар оролдож буй нэгэн, агуу цагаан сэнтийгээс зугтдаг хүүхэлдэй, урвагч гэж хэлнэ. Бурхан нүдэн дээр нь зугтаж байгаа тэрслүү хэнийг ч болов өршөөхгүй. Ийм хүмүүс илүү хүнд шийтгэл хүртэх болно. Бурханы өмнө шүүгдэхээр очиж, улмаар ариусгагдсан хүмүүс Бурханы хаанчлалд үүрд амьдарна. Мэдээж энэ нь ирээдүйд тохиох зүйл юм.

Шүүлтийн ажил бол Бурханы Өөрийн ажил тул мэдээж үүнийг Бурхан Өөрөө хийх ёстой; хүн Түүний оронд хийж чадахгүй. Шүүлт бол үнэнийг ашиглан хүн төрөлхтнийг байлдан дагуулах явдал учраас, энэ ажлыг хүмүүсийн дунд хийхээр Бурхан дахиад л бие махбод болсон дүрээрээ гарч ирэх нь дамжиггүй юм. Өөрөөр хэлбэл, эцсийн өдрүүдэд Христ газар дэлхий даяарх хүмүүсийг сургахын тулд үнэнийг ашиглаж, бүх үнэнийг тэдэнд мэдэгдэнэ. Энэ бол Бурханы шүүлтийн ажил юм. Хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханы тухайд олон хүн таагүй сэтгэгдэлтэй байдаг, учир нь Бурхан шүүлтийн ажил хийхийн тулд махбод болно гэдэгт итгэхэд хүнд хэцүү байдаг. Гэсэн хэдий ч, Бурханы ажил үргэлж хүний таамаглалаас хол давдаг ба хүний оюун ухаанаар үүнийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү гэдгийг чамд Би хэлэх ёстой. Учир нь хүн бол газар дээрх өт хорхой төдий байхад Бурхан бол орчлон ертөнцийг дүүргэдэг дээдийн дээд Нэгэн билээ; хүний оюун ухаан бол өт хорхой үрждэг бохир устай нүх адил байхад Бурханы бодлоор удирдуулдаг ажлын үе шат бүр нь Бурханы мэргэн ухааны охь юм. Хүн үргэлж Бурхантай барьцахыг хүсдэг ба эцэстээ хэн нь хохирол амсах нь илэрхий юм гэж Би хэлдэг. Би та бүхэнд өөрсдийгөө алтнаас үнэтэй мэт бүү сана гэж захих байна. Бусад нь Бурханы шүүлтийг хүлээж авч чадаж байхад чи яагаад чадахгүй гэж? Чи бусдаас хэр дээгүүр байдаг вэ? Бусад нь үнэний өмнө толгой бөхийж чадаж байхад чи ч бас яагаад чадахгүй гэж? Бурханы ажилд зогсоохын аргагүй хөдөлгөх хүч байдаг. Чамайг “хувь нэмэр” оруулсан төдийд л Тэр шүүлтийн ажлыг дахин давтахгүй бөгөөд ийм сайхан боломжийг алдсандаа чи харуусалд автана. Хэрвээ чи Миний үгэнд итгэхгүй байвал тэнгэр дэх тэр агуу цагаан сэнтий чамд шүүлт оноохыг хүлээ! Бүх израилчууд Есүсийг басамжлан үгүйсгэсэн боловч хүн төрөлхтнийг Есүс золин аварсан баримт орчлон ертөнц даяар, дэлхийн өнцөг булан бүрд түгсэн гэдгийг чи мэдэх ёстой. Бурханы аль эрт бүтээсэн бодит байдал энэ биш гэж үү? Есүс чамайг тэнгэрт аваачна гэж чи хүлээсээр л байгаа бол Би чамайг зөрүүд үжирсэн мод[a] юм гэж хэлнэ. Үнэнд үнэнч биш, зөвхөн ерөөл эрж

[a] Үжирсэн мод: “ямар ч нэмэргүй” гэсэн утгатай хятад хэлц.

хайдаг чам шиг хуурамч итгэгчийг Есүс хүлээн зөвшөөрөхгүй. Эсрэгээрээ, Тэр чамайг хэдэн арван мянган жилийн турш галт нуурт шатаахаар хаяхдаа огтхон ч өршөөл үзүүлэхгүй.

Чи одоо шүүлт гэж юу болохыг, үнэн гэж юу болохыг ойлгож байна уу? Ойлгосон бол Би чамайг шүүлтэд дуулгавартай захирагд гэж захья, эс бөгөөс чи Бурханаар сайшаагдах, Бурханаар хаанчлалд нь хүргүүлэх боломжийг хэзээ ч олж авахгүй. Шүүлтийг л хүлээн зөвшөөрдөг боловч хэзээ ч ариусгагдаж чадахгүй хүмүүс, өөрөөр хэлбэл, шүүлтийн ажлын ид дундуур зугтдаг хүмүүс үүрд Бурханаар жигшигдэн, гологдох болно. Тэд Бурханаас урваж, Бурханы эсрэг тэрсэлсэн учир нүгэл нь фарисайчуудынхаас арвин агаад хүнд. Үйлчлэл үзүүлэхэд ч тохирохгүй ийм хүмүүс илүү хатуу хэр нь бас мөнхийн шийтгэлийг хүлээн авах болно. Нэгэнтээ үнэнч байдлаа үгээр харуулсан боловч, дараа нь Өөрөөс нь урвасан ямар ч урвагчийг Бурхан өршөөхгүй. Ийм хүмүүс сүнс, сэтгэл, биеийн шийтгэлээр дамжуулан цээрлүүлэлт хүртэнэ. Энэ нь яг Бурханы зөвт зан чанарын илчлэл биш гэж үү? Хүнийг шүүж, илчилдэг Бурханы зорилго энэ биш гэж үү? Шүүлтийн явцад төрөл бүрийн хорон муу үйл хийсэн бүх хүнийг Бурхан муу ёрын сүнсээр дүүрсэн газар орон луу илгээдэг бөгөөд тэдгээр муу ёрын сүнсний зоргоор махан биеийг нь устгуулахад тэдний биеэс хүүрийн үнэр ханхалдаг. Энэ нь тэдэнд тохирох цээрлүүлэлт юм. Бурхан тэдгээр үнэнч бус хуурамч итгэгч, хуурамч элч, хуурамч ажилчдын хийсэн нүгэл нэг бүрийг бүртгэлийн номд нь бичиж авдаг; тэгээд цаг нь ирэхэд Тэр тэднийг хэзээ ч бүү дахин төрөг, дахин хэзээ ч бүү гэрэл үзэг гэж бохир сүнснүүдийн дунд хаяж, бүхий л биеийг нь эдгээр бохир сүнсээр бузарлуулдаг. Нэгэн цагт үйлчлэл хийсэн боловч эцсийг нь хүртэл үнэнч үлдэж чаддаггүй эдгээр хоёр нүүртнийг Бурхан хорон муу хүмүүсийн тоонд оруулдаг ба ингэснээр тэд хорон муу нэгний зөвлөгөөн дор алхаж, эмх замбараагүй бүлгийнх нь нэг хэсэг болдог; эцэст нь Бурхан тэднийг үндсээр нь устгана. Христэд хэзээ ч үнэнч байгаагүй, ямар ч хүчин чармайлт зориулаагүй хүмүүсийг Бурхан хөсөр хаяж, хэзээ ч ойшоохгүй бөгөөд эрин үе солигдоход тэднийг бүгдийг нь устгана. Тэд Бурханы хаанчлалд орж чадах нь байтугай, газар дээр ч оршин байхаа болино. Бурханд хэзээ ч чин үнэнч байгаагүй, харин нөхцөл байдлын улмаас Түүнтэй ёс төдий харьцахаас аргагүйд хүрсэн хүмүүс нь Түүний ардуудын төлөө үйлчлэл хийдэг хүмүүсийн тоонд ордог. Ийм хүмүүсээс цөөн хэд нь л амьд үлдэж чаддаг ба ихэнх нь үйлчлэл хийхэд ч тэнцэхгүй хүмүүсийн хамтаар мөхөх болно. Эцэст нь Бурханы ардууд, хөвгүүд болон тахилч болгохоор Бурханы урьдчилан тогтоосон хүмүүс зэрэг Өөртэй нь санаа нэгтэй бүх хүнийг Бурхан хаанчлалдаа аваачна. Тэд Бурханы ажлын охь нь байх болно. Бурханы тогтоосон ангиллын алинд нь ч багтаж чаддаггүй хүмүүсийн тухайд гэвэл, тэд үл итгэгчдийн тоонд орно. Тэдний үр дүн ямар байхыг та нар лавтай төсөөлж чадна. Та нарт хэлэх ёстой бүхнээ Би аль хэдийн хэлсэн; ямар замыг сонгох нь бүгд зөвхөн өөрсдийн чинь сонголт. Та нарын ойлгох ёстой зүйл бол энэ: Бурханы ажил Бурхантай хөл

нийлүүлж чадахгүй хэнийг ч, хэзээ ч хүлээдэггүй ба Бурханы зөвт зан чанар ямар ч хүнд өршөөл үзүүлдэггүй.

БУРХАН ХҮМҮҮСИЙН ДУНД АГУУ ЗҮЙЛ ХИЙСНИЙГ ЧИ МЭДСЭН ҮҮ?

Хуучин эрин үе улирч, шинэ эрин үе ирлээ. Жилээс жилд, өдрөөс өдөрт Бурхан маш их ажил хийжээ. Тэр дэлхийд ирээд, дараа нь буцсан. Энэ мөчлөг өөрөө олон үе дамжин давтагдсан билээ. Өнөөдөр Бурхан урьдын адилаар хийх ёстой ажлаа болон хараахан гүйцээгээгүй ажлаа үргэлжлүүлэн хийдэг, учир нь өнөөдрийг хүртэл Тэрээр амралтад орж амжаагүй юм. Бүтээлийн цагаас өнөөг хүртэл Бурхан их ажил хийсэн. Гэхдээ Бурхан өнөөдөр урьдынхаас хавьгүй их ажил хийж буйн дээр Түүний ажлын цар хүрээ өмнөхөөсөө ч асар их гэдгийг чи мэдсэн үү? Ийм учраас л Би Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийсэн гэж хэлдэг. Бурханы бүх ажил хүнд ч бай, Бурханд ч бай маш чухал, учир нь Түүний ажлын хэсэг бүр хүнтэй холбоотой.

Бурханы ажил харагдашгүй, хүршгүй—дэлхий ертөнцөд бүр ч харагддаггүй юм бол агуу зүйл байж яаж чадах юм бэ? Ямар зүйлийг агуу гэж үзэх вэ? Мэдээж, Бурханы хийдэг ямар ч ажлыг агуу гэж үзэж болно гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй, гэхдээ өнөөдөр Бурханы хийж буй ажлын тухай Би яагаад ингэж хэлдэг вэ? Бурхан агуу зүйл хийсэн гэж Намайг хэлэх үед үүнд хүний хараахан ойлгоогүй олон нууц агуулагдаж байгаа нь эргэлзээгүй. Одоо тэдгээрийн тухай ярилцъя.

Есүс Өөрийнх нь оршин тогтнолыг тэвчиж чадаагүй эрин үед тэжээлийн онгоцонд төрсөн ч гэлээ дэлхий ертөнц Түүнд саад болж чадаагүй. Тэрээр Бурханы халамж дор гучин гурван жилийн турш хүмүүсийн дунд амьдарсан. Энэ олон жил амьдрахдаа Тэрээр хорвоогийн гашууныг туулж, газар дээрх гаслант амьдралыг амссан юм. Тэгээд бүх хүн төрөлхтнийг золин аврахын тулд цовдлогдох асар их ачаа үүрчээ. Тэрээр Сатаны эзэмшил дор амьдарч байсан бүх нүгэлтнийг золин аварч, эцэст нь дахин амилсан биеэрээ амрах газар луугаа буцсан юм. Одоо Бурханы шинэ ажил эхэлсэн ба энэ нь бас шинэ эрин үеийн эхлэл билээ. Бурхан авралын шинэ ажлаа эхлүүлэхийн тулд золин аврагдсан хүмүүсийг гэртээ авчирдаг. Энэ удаад авралын ажил урьд өмнөхөөс ч илүү нэгд нэггүй байдаг. Хүнийг өөрөөр нь өөрчлүүлэхийн тулд Ариун Сүнс хүний дотор ажилладаггүй, мөн энэ ажлыг хийхээр Есүсийн бие ч хүмүүсийн дунд гарч ирдэггүй бөгөөд тэр тусмаа энэ ажил өөр аргаар бүр ч хийгддэггүй. Харин ч бие махбодтой болсон Бурхан л энэ ажлыг хийж, Өөрөө удирдан чиглүүлдэг. Тэрээр хүнийг шинэ ажил руу хөтлөхийн тулд ийм маягаар хийдэг. Энэ нь агуу зүйл биш гэж үү? Бурхан энэ ажлыг хүн төрөлхтний нэг хэсгээр, эсвэл зөгнөх аргаар дамжуулан хийдэггүй; харин Бурхан Өөрөө үүнийг хийдэг. Энэ бол агуу зүйл биш бөгөөд хүнд баяр хөөрийн

дээдийг авчирч чадахгүй гэж зарим нь хэлж магад. Гэвч Би та нарт Бурханы ажил ердөө энэ биш, харин хавьгүй агуу, хамаагүй илүү их зүйл юм гэдгийг хэлэх байна.

Энэ удаа Бурхан сүнслэг биеэр биш, харин тун эгэл жирийн биеэр ажиллахаар ирсэн. Түүнээс гадна, энэ нь Бурханы махбод болсон хоёр дахь бие төдийгүй, бас махбодод Бурханы эргэн ирсэн бие юм. Энэ бол маш эгэл жирийн махбод. Чи Түүнээс бусдаас онцгойроод байх зүйл юу ч олж харж чадахгүй ч урьд өмнө нь хэзээ ч сонсож байгаагүй үнэнийг Түүнээс олж авах боломжтой. Энэ өчүүхэн жаахан махбод л Бурханаас ирсэн үнэний бүх үгийн биелэл болж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг гүйцэтгэж, хүнд ойлгуулахын тулд Бурханы зан чанарыг бүхэлд нь илэрхийлдэг. Чи тэнгэр дэх Бурханыг харахыг үнэхээр их хүсдэггүй гэж үү? Чи тэнгэр дэх Бурханыг ойлгохыг үнэхээр их хүсдэггүй гэж үү? Чи хүн төрөлхтний хүрэх газрыг харахыг үнэхээр их хүсдэггүй гэж үү? Тэр чамд өөр хэний ч хэлж чадаагүй энэ бүх нууцыг хэлнэ, Тэр бас чиний ойлгодоггүй үнэнийг хэлж өгнө. Тэр бол хаанчлалд орох чиний хаалга, шинэ эрин үе рүү дагуулах чиний хөтөч юм. Ийм эгэл жирийн махбод ойлгохын аргагүй олон нууцыг агуулдаг. Түүний үйл хэрэг чамд ойлгомжгүй байж болох ч Тэр бол хүмүүсийн боддог шиг энгийн махбод биш гэдгийг хийж буй ажлынх нь бүхий л зорилго чамд хангалттай харуулдаг. Учир нь Тэрээр эцсийн өдрүүд дэх Бурханы хүслийг болон хүн төрөлхтөнд Бурханы үзүүлсэн хайр халамжийг төлөөлдөг. Хэдийгээр чи тэнгэр, газрыг доргиох мэт Түүний үгийг сонсож чадахгүй, галын дөл мэт дүрэлзэн буй Түүний нүдийг харж чадахгүй, мөн Түүний төмөр сабааны сахилгажуулалтыг хүлээн авч чадахгүй ч Түүний үгээс Бурхан уур хилэнтэй гэдгийг сонсож, Бурхан хүн төрөлхтөнд энэрэнгүй ханддагийг мэдэж авч чадна; чи Бурханы зөвт зан чанар, мэргэн ухааныг олж харахын сацуу бүх хүн төрөлхтнийг гэх Бурханы анхаарал халамжийг ухаарч чадна. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил нь тэнгэр дэх Бурхан газар дээрх хүмүүсийн дунд амьдарч байгааг хүнд харуулж, Бурханыг мэдэх, дуулгавартай дагах, хүндэтгэх, хайрлах боломжийг хүмүүст олгохын төлөө байдаг. Ийм учраас Тэр махбодоор хоёр дахь удаагаа эргэж ирсэн. Өнөөдөр хүмүүсийн хардаг зүйл бол хүнтэй адилхан, нэг хамар, хоёр нүдтэй, гойд зүйлгүй Бурхан ч гэлээ, хэрэв энэ хүн байгаагүй бол тэнгэр, газар асар их өөрчлөгдөх байсан, мөн энэ хүн байгаагүй бол тэнгэр бүүдийж, газар дэлхий эмх замбараагүй байдалд автан, бүх хүн төрөлхтөн өлсгөлөн, тахал дунд амьдрах байсан гэдгийг эцэст нь Бурхан та нарт харуулна. Хэрэв бие махбодтой болсон Бурхан эцсийн өдрүүдэд та нарыг аврахаар ирээгүй бол Бурхан бүх хүн төрөлхтнийг аль эрт тамд устгах байсан; хэрэв энэ махбод байгаагүй бол та нар үүрд хүнд нүгэлтэн болж, үргэлжийн мөнхөд цогцос болох байсныг Тэр та нарт харуулна. Хэрэв энэ махбод байгаагүй бол бүх хүн төрөлхтөнд зайлахын аргагүй гамшиг нүүрлэж, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд Бурханы оноох илүү хүнд шийтгэлээс зайлж зугтах боломжгүй болох байсныг та нар мэдэх ёстой. Хэрэв энэхүү эгэл жирийн махбод төрөөгүй бол та нар бүгд амьдарч чадахгүй атлаа амьдрал гуйж, үхэж чадахгүй мөртөө үхлийн төлөө залбирах

байдалд орох байлаа. Хэрэв энэ махбод байгаагүй бол та нар үнэнийг олж авч, өнөөдрийн Бурханы сэнтийн өмнө ирж чадахгүй, харин жигшүүрт нүглийнхээ улмаас Бурханд шийтгүүлэх байсан юм. Хэрвээ Бурхан махбодоор эргэж ирээгүй бол хэнд ч аврагдах боломж олдохгүй байх байсан; энэ махбод ирээгүй бол Бурхан аль эрт хуучин эрин үеийг төгсгөх байсан гэдгийг та нар мэдсэн үү? Ийм байтал, хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханыг та нар голсоор байж чадна гэж үү? Та нар энэхүү эгэл жирийн хүнээс маш их ашиг тус хүртэж чадах байтал яагаад Түүнийг баяртайгаар хүлээн авахгүй байна вэ?

Бурханы ажил бол чиний ойлгож ухаарч чадахгүй зүйл юм. Хэрвээ чи сонголт чинь зөв эсэхийг ч бүрэн ухаарч чадахгүй, Бурханы ажил амжилт олох эсэхийг ч мэдэж чадахгүй бол азаа үзээд, энэхүү эгэл жирийн хүн чамд асар их тус хүргэх эсэхийг, мөн Бурхан үнэхээр агуу ажлыг хийсэн эсэхийг харж яагаад болохгүй гэж? Гэвч, Ноагийн цаг үед хүмүүс Бурханы хувьд харж тэвчишгүй байх хэмжээнд идэж уун, гэрлэж, нөхөрт гарч байсан тул Тэрээр хүн төрөлхтнийг утсгахын тулд асар их үер буулган, зөвхөн Ноагийн гэр бүлийн найман хүн болон бүх төрлийн жигүүртэн шувууд, араатан амьтдыг өршөөсөн гэдгийг Би чамд хэлэх ёстой. Гэхдээ эцсийн өдрүүдэд Бурханы өршөөсөн хүмүүс бол эцсээ хүртэл Түүнд үнэнч байсан бүх хүн юм. Энэ хоёр эрин үе нь Бурханы хувьд харж тэвчишгүй асар их завхралын үе байсан ба хоёр эрин үе дэх хүн төрөлхтөн маш их завхарч, Бурхан бол өөрсдийнх нь Эзэн гэдгийг үгүйсгэсэн хэдий ч Бурхан зөвхөн Ноагийн цаг үеийн хүмүүсийг л устгасан билээ. Хоёр эрин үеийн хүн төрөлхтөн Бурханд асар их уй гашуу учруулсан ч Бурхан эцсийн өдрүүдийн хүмүүст өдийг хүртэл тэвчээртэй хандсан. Яагаад тэр вэ? Та нар үүнд гайхаж байгаагүй гэж үү? Хэрвээ та нар үнэхээр мэдэхгүй байгаа бол Би хэлээд өгье. Бурхан эцсийн өдрүүдэд хүмүүст нигүүлсэл хайрлаж чаддагийн учир нь хүмүүс Ноагийн цаг үеийн хүмүүсээс бага завхарснаас, эсхүл тэд Бурханд гэмшлээ харуулснаас болоогүй, эцсийн өдрүүдийн технологи маш их хөгжсөн болохоор Бурхан түүнийг нь устгаж чадахгүй байгаагаас бүр ч болоогүй. Харин ч Бурхан эцсийн өдрүүд дэх бүлэг хүмүүст ажлаа хийх ёстой ба Бурхан Өөрөө бие махбодтой болоод энэ ажлыг хийнэ. Түүнчлэн Бурхан энэ бүлгийн нэг хэсгийг авралынхаа бай, удирдлагын төлөвлөгөөнийхөө үр жимс болгохоор сонгож, энэ хүмүүсийг дараачийн эрин үед аваачна. Тиймээс, ямартай ч Бурханы төлсөн төлөөс нь бүхэлдээ эцсийн өдрүүдэд Өөрийн махбод болсон биеэр хийх гэж буй ажлынх нь бэлтгэл байв. Энэхүү махбодын ачаар л та нар өнөөдрийг хүрсэн. Бурхан махбодоор амьдардаг учир та нарт амьд үлдэх боломж бий. Энэ бүх зол завшаан нь энэхүү эгэл жирийн хүнээс улбаатай билээ. Үүгээр ч зогсохгүй, эцэст нь улс орон бүр энэ эгэл жирийн хүнийг шүтэн мөргөхийн сацуу энэ өчүүхэн жаахан хүнд талархаж, түүнийг дуулгавартай дагана, учир нь Түүний авчирсан үнэн, амь, зам нь бүх хүн төрөлхтнийг аварч, хүн Бурхан хоёрын дундах зөрчлийг зөөлрүүлж, хоорондох зайг нь багасгаж, Бурхан хүн хоёрын бодлыг холбосон юм. Тэрээр мөн Бурханы төлөө бүр ч агуу их алдар сууг олж авсан билээ.

Ийм эгэл жирийн хүн чиний итгэл, бишрэлийг хүртэхэд зохисгүй гэж үү? Ийм эгэл жирийн махбод Христ гэж дуудуулахад тохирохгүй гэж үү? Ийм эгэл жирийн хүн бусад хүмүүсийн дунд Бурханы илэрхийлэл болж чадахгүй гэж үү? Хүн төрөлхтнийг гамшгаас гэтэлгэсэн ийм хүн Түүнийг гэх хайр, хүслийг чинь хүртэх эрхгүй гэж үү? Та нар Түүний амаар илэрхийлэгдсэн үнэнийг голж, та нарын дундах Түүний оршин тогтнолыг жигших юм бол эцэстээ юу болж хоцрох вэ?

Бурханы эцсийн өдрүүд дэх бүх ажил энэ эгэл жирийн хүнээр дамжин хийгддэг. Тэрээр бүхнийг чамд хайрлах болно, тэгээд ч зогсохгүй чамд хамаатай бүхнийг шийдэж чадна. Ийм хүн та нарын боддог шиг дурдахын ч хэрэггүй тийм энгийн хүн байж болох уу? Түүний үнэн та нарыг бүрэн үнэмшүүлэхэд хангалтгүй гэж үү? Түүний үйл хэргийг харах нь та нарыг бүрэн үнэмшүүлэхэд хангалтгүй гэж үү? Эсхүл Түүний авчирдаг зам цааш алхахад чинь зохисгүй гэж үү? Эцсийн эцэст Түүнийг зэвүүцэж, Түүнийг хаяж, Түүнээс зайлсхийх ямар шалтгаан та нарт байна вэ? Энэ хүн л үнэнийг илэрхийлдэг, энэ хүн л үнэнээр хангадаг, энэ хүн л та нарт дагах зам өгдөг. Та нар эдгээр үнэн дотроос Бурханы ажлын ул мөрийг хайж олж чадахгүй хэвээр байгаа юм гэж үү? Есүсийн ажил байгаагүй бол хүн төрөлхтөн загалмайгаас бууж чадахгүй байсан, харин өнөөдрийн бие махбодтой болсон Бурхан байгаагүй бол загалмайгаас буусан хүмүүс Бурханы сайшаалыг хэзээ ч хүртэж чадахгүй, эсвэл шинэ эрин үед орж чадахгүй байх байлаа. Энэ эгэл жирийн хүн ирээгүй бол Бурханы жинхэнэ төрхийг харах боломж та нарт хэзээ ч олдохгүй, та нар шаардлага ч хангахгүй байх байсан, учир нь та нар бүгд аль эрт устгагдах ёстой байсан бай юм. Бурхан хоёр дахь удаагаа бие махбодтой болон ирсэн учраас та нарыг уучилж, өршөөл үзүүлсэн. Ямартай ч, эцэст нь та бүхэнд хэлэх ёстой үг минь бол энэ: Бие махбодтой болсон Бурхан буюу энэ эгэл жирийн хүн та нарт амин чухал юм. Энэ бол хүмүүсийн дунд Бурханы аль хэдийн хийсэн агуу зүйл билээ.

ЭЦСИЙН ӨДРҮҮДИЙН ХРИСТ Л ХҮНД МӨНХ АМИЙН ЗАМЫГ ӨГЧ ЧАДНА

Амийн зам бол хэн бүхний эзэмшиж чадах зүйл биш, хэн нэгний хялбархан олж авч чадах зүйл ч биш. Учир нь амь зөвхөн Бурханаас ирдэг, өөрөөр хэлбэл, Бурхан Өөрөө л амийн мөн чанарыг эзэмшдэг ба Бурханд Өөрт нь л амийн зам бий. Иймээс Бурхан л амийн эх сурвалж, амийн амьд усны ширгэшгүй урсах эх ундарга юм. Бурхан дэлхий ертөнцийг бүтээснээсээ хойш амийн эрч хүчтэй холбоотой, хүнд амь авчрах ихээхэн ажил хийсэн бөгөөд хүнд амь олж авах боломж олгохын тулд асар их төлөөс төлсөн. Учир нь Бурхан Өөрөө мөнх амь, Бурхан Өөрөө хүнийг амилуулах зам билээ. Бурхан үргэлж хүний зүрх сэтгэлд оршиж, цаг үргэлжид хүмүүсийн дунд амьдардаг. Тэр хүний амьдралын хөдөлгөгч хүч, хүний оршин тогтнолын үндэс, мэндэлснээс нь хойших хүний оршин тогтнолын баялаг хөрөнгө

байсаар ирсэн билээ. Тэр хүнийг дахин төрөхөд хүргэж, үүрэг бүрдээ тууштайгаар амьдрах боломж олгодог. Түүний хүч чадал, бөхөшгүй амийн хүчний ачаар хүн үеэс үед амьдарч, энэ хугацаанд Бурханы амийн хүч чадал нь хүний оршин тогтнолын гол тулгуур болж ирсэн бөгөөд Бурхан ямар ч эгэл хүний төлж байгаагүй төлөөсийг төлсөн юм. Бурханы амийн хүч нь ямар ч хүч чадлыг дийлж чадна; түүнчлэн ямар ч хүч чадлаас давуу байдаг. Түүний амь бол мөнхийн, Түүний хүч чадал ер бусын, Түүний амийн хүчийг ямар ч бүтээгдсэн зүйл, ямар ч дайсны хүч дийлж чадахгүй. Бурханы амийн хүч цаг хугацаа, орон зайг үл хамааран оршиж, гэрэлт цацрагаа гэрэлтүүлдэг. Тэнгэр газарт асар их өөрчлөлт гарч болох ч Бурханы амь үүрд нэг хэвээр байдаг. Бүх зүйл урсан өнгөрдөг ч Бурханы амь байсаар л байдаг. Учир нь Бурхан бол бүх зүйлийн оршин тогтнолын эх сурвалж ба тэдний оршин тогтнолын үндэс билээ. Хүний амь Бурханаас эхтэй, тэнгэрийн оршин тогтнол Бурханаас үүдэлтэй ба газрын оршин тогтнол Бурханы амийн хүчнээс улбаатай. Амин чанар бүхий ямар ч зүйл Бурханы дээд эрхээс давж чадахгүй, ямар ч эрч хүчтэй зүйл Бурханы эрх мэдлийн хил хязгаарыг эвдэж чадахгүй. Ийм маягаар хэн ч бай бүгд Бурханы ноёрхол дор захирагдаж, Бурханы тушаал дор амьдрах ёстой ба хэн ч Түүний хяналтаас зугтаж чадахгүй.

Магадгүй одоо чи амийг хүлээн авч, үнэнийг олж авахыг хүсэж болно. Ямартай ч чи Бурханыг олохыг, өөрийн итгэж найдаж болох, өөрийг чинь мөнх амиар хангах Бурханыг олохыг хүсдэг. Хэрвээ мөнх амийг олж авахыг хүсвэл эхлээд чи мөнх амийн эх сурвалжийг ойлгож, Бурхан хаана байдгийг мэдэх ёстой. Зөвхөн Бурхан хувиршгүй амь бөгөөд Бурханд л амийн зам байдаг гэж Би аль хэдийн хэлсэн. Бурхан нэгэнт хувиршгүй амь учраас Тэр бол мөнх амь; Бурхан л амийн зам учраас Бурхан Өөрөө мөнх амийн зам юм. Ийм болохоор чи эхлээд Бурхан хаана байдгийг, мөнх амийн энэ замыг хэрхэн олж авахыг ойлгох ёстой. Одоо энэ хоёр асуудлыг тус тусад нь нөхөрлөцгөөе.

Хэрвээ чи мөнх амийн замыг олж авахыг үнэхээр хүсвэл, үүнийг хайх уйгагүй эрмэлзэлтэй бол энэ асуултад эхлээд хариул: Өнөөдөр Бурхан хаана байгаа вэ? Бурхан тэнгэрт амьдардаг гэж чи хариулах байх, мэдээж Тэр танай гэрт амьдрахгүй нь лавтай, тийм биз? Магадгүй чи Бурхан бүх зүйлийн дунд амьдардаг нь мэдээжийн хэрэг гэж хэлэх байх. Эсвэл чи Бурхан хүн бүрийн зүрх сэтгэлд амьдардаг, аль эсвэл Бурхан сүнсний ертөнцөд байдаг гэж хэлж магад. Би үүний алийг нь ч үгүйсгэдэггүй, гэхдээ Би энэ асуудлыг та нарт тодорхой болгох ёстой. Бурхан хүний зүрх сэтгэлд амьдардаг гэж хэлэх нь тийм ч зөв биш, бас тэр чигтээ буруу ч биш юм. Учир нь Бурханд итгэгчдийн дунд итгэл нь жинхэнэ эсвэл хуурамч, Бурханд сайшаагддаг эсвэл сайшаагддаггүй, таалалд нь нийцдэг эсвэл жигшигддэг, Бурханы төгс болгодог эсвэл таягдан хаядаг хүмүүс гэж бий. Иймд Би Бурхан цөөн хэдэн хүний л зүрх сэтгэлд амьдардаг гэж хэлнэ, харин энэ хүмүүс нь эргэлзэх юмгүйгээр Бурханд үнэхээр итгэдэг, Бурханаар сайшаагдаж, таалалд нь нийцдэг, Түүний төгс болгодог хүмүүс юм. Тэд бол Бурханаар удирдуулдаг хүмүүс мөн. Тэд

Бурханаар удирдуулдаг учраас Бурханы мөнх амийн замыг аль хэдийн сонссон, үзсэн хүмүүс юм. Бурханд итгэх итгэл нь хуурамч, Бурханд сайшаагддаггүй, Бурханы үзэн ядаж, таягдан хаядаг хүмүүс нь Бурханд гологдож, амийн замыг ололгүй, Бурхан хаана байгааг ч мэдэхгүй хэвээр үлдэх тавилантай. Эсрэгээрээ, зүрх сэтгэлд нь Бурхан амьдардаг хүмүүс Түүний хаана байгааг мэддэг. Тэд бол Бурханы мөнх амийн замаа хайрласан, Бурханыг дагадаг хүмүүс юм. Одоо чи Бурхан хаана байгааг мэдсэн үү? Бурхан хүний зүрх сэтгэлд, мөн хүний хажууд бий. Тэр зөвхөн сүнсний ертөнцөд, бүх зүйлийн дээр оршоод зогсохгүй хүний оршин байдаг газар дэлхий дээр ч байдаг. Иймээс эцсийн өдрүүд ирж, Бурханы ажлын алхмуудыг шинэ хүрээнд авчирсан. Бурхан бүх зүйлийн дундах юм бүрийг захирдаг, хүний зүрх сэтгэл дэх түшиг тулгуур төдийгүй Тэр хүмүүсийн дунд оршдог. Ийм маягаар л Тэр хүн төрөлхтөнд амийн замыг авчирч, амийн зам руу хүн төрөлхтнийг аваачдаг. Бурхан газар дэлхий дээр ирж, хүмүүсийн дунд амьдарснаар хүн амийн замыг олж, оршин тогтнох боломжтой болдог. Үүний зэрэгцээ Бурхан бас хүмүүсийн дундах Өөрийн удирдлагатай хамтран ажиллуулахын тулд бүх зүйлийн дундах юм бүрийг удирдаг чиглүүлдэг. Иймээс хэрвээ чи Бурхан тэнгэрт болоод хүний зүрх сэтгэлд байдаг гэсэн сургаалыг л хүлээн зөвшөөрдөг атлаа хүмүүсийн дундах Бурханы оршин тогтнолын үнэнийг эс зөвшөөрөх аваас амийг болон үнэний замыг хэзээ ч олж авахгүй.

Бурхан Өөрөө амь ба үнэн бөгөөд Түүний амь ба үнэн зэрэгцэн оршдог. Үнэнийг олж авах чадваргүй хүмүүс амийг хэзээ ч олж авахгүй. Үнэний удирдамж, дэмжлэг, хангалтгүйгээр чи бичиг үсэг, хоосон сургаал болон үхлийг л олж авна. Бурханы амь үргэлжид оршин байдаг бөгөөд Түүний үнэн ба амь нь зэрэгцэн оршдог. Хэрвээ үнэний эх сурвалжийг олж чадахгүй бол чи амийн тэжээлийг олж авахгүй; хэрвээ амийн хангалтыг олж авч чадахгүй бол чамд мэдээж үнэн байхгүй байх болно, иймээс үзэл, төсөөллийг эс тооцвол чиний бие бүхэлдээ өмхий махан биеэс өөр юу ч биш юм. Номын үгийг амь хэмээн тооцдоггүй, түүхийн бичээсийг үнэн гэж шүтэж болдоггүй, хуучны дүрэм журам нь Бурханы өнөөгийн хэлдэг үгийн бүртгэл болж чадахгүй гэдгийг мэдэж ав. Бурхан газар дэлхий дээр ирж, хүмүүсийн дунд амьдрахдаа илэрхийлдэг зүйл нь л зөвхөн үнэн, амь, Бурханы хүсэл бөгөөд Түүний өнөөгийн ажлын арга зам юм. Хэрвээ чи Бурханы өнгөрсөн эрин үеүдэд хэлсэн үгийн тэмдэглэлийг өнөөдөр хэрэглэх аваас чамайг археологич, бас түүхэн өвийн мэргэжилтэн гэж тодорхойлбол хамгийн оновчтой. Учир нь чи үргэлж Бурханы өнгөрсөн цаг үед хийсэн ажлын ул мөрт итгэдэг, хүмүүсийн дунд урьд нь ажиллахад нь Бурханаас үлдсэн сүүдэрт итгэдэг, хуучин цаг үед Бурханы дагалдагч нартаа өгсөн замд итгэдэг, харин Бурханы өнөөгийн ажлын чиглэлд итгэдэггүй, Бурханы өнөөгийн алдар суутай төрх байдалд итгэдэггүй ба Бурханы өнөө үед илэрхийлсэн үнэний замд итгэдэггүй. Иймээс чи бодит байдлаас бүрэн тасарсан мөрөөдөгч гэдэг нь гарцаагүй юм. Хэрвээ чи одоо ч гэсэн хүнд амь авчрах чадалгүй бичиг үсэгтэй зууралдсаар байгаа бол чи

хэрэггүй үжирсэн мод[a], учир нь чи хэт хуучинсаг, зөрүүд, үгэнд ордоггүй!

Махбод болсон Бурханыг Христ гэдэг, иймээс хүмүүст үнэнийг өгч чаддаг Христийг Бурхан гэдэг. Энэ тухайд ямар ч хэтрүүлсэн зүйл байхгүй, учир нь Түүнд Бурханы мөн чанар болон хүний хүрэх боломжгүй Бурханы зан чанар, Бурханы ажлын мэргэн ухаан байдаг. Өөрсдийгөө Христ гэдэг атлаа Бурханы ажлыг хийж чаддаггүй хүмүүс хуурамч юм. Христ бол газар дэлхий дээрх Бурханы илрэл төдий биш, харин хүмүүсийн дунд ажлаа хэрэгжүүлж, гүйцэлдүүлэхдээ Бурханы авсан онцгой махбод билээ. Энэ махбод нь газар дээрх Бурханы ажлыг хангалттай сайн хийж, Бурханы зан чанарыг илэрхийлж, Бурханы сайн төлөөлөл байж, хүнийг амиар хангаж чаддаг учир хэн ч үүнийг орлож чадахгүй. Христийг дуурайдаг хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт бүгд унах болно, учир нь тэд өөрсдийгөө Христ гэцгээдэг ч Христийн ямар ч мөн чанарыг эзэмшдэггүй. Иймээс, Христийн жинхэнэ байдлыг хүн тодорхойлох боломжгүй, харин Бурхан Өөрөө үүнийг хариулж, шийддэг гэж Би хэлж байна. Ийм байдлаар, үнэхээр амийн замыг эрж хайхыг хүсвэл чи Бурхан газар дэлхий дээр ирснээр хүнд амийн замыг өгөх ажлыг хийдэг гэдгийг эхлээд хүлээн зөвшөөрөх ёстой, мөн эцсийн өдрүүдэд Тэрээр хүнд амийн замыг өгөхөөр газар дэлхий дээр ирдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ нь өнгөрсөн үе биш; харин өнөөдөр тохиолдож байгаа юм.

Эцсийн өдрүүдийн Христ амийг, өнө удаан мөнхөд үргэлжлэх үнэний замыг авчирдаг. Энэ үнэн бол хүн амийг олж авах арга зам, нөгөөтээгүүр хүн Бурханыг мэдэж, Бурханаар сайшаагдах цорын ганц арга зам юм. Хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийн өгсөн амийн замыг эрж хайхгүй бол хэзээ ч Есүсийн сайшаалыг олж, тэнгэрийн хаанчлалын үүдээр орох шаардлагыг хангаж чадахгүй. Учир нь чи бол түүхийн хоригдол агаад утсан хүүхэлдэй юм. Дүрэм журам, бичиг үсэгт захирагдаж, түүхэнд дөнгөлүүлсэн хүмүүс хэзээ ч амийг олж авч чадахгүй, мөнх амийн замыг ч бас хэзээ ч олж авч чадахгүй. Яагаад гэвэл, тэдэнд байгаа бүхэн бол сэнтийгээс урсах амийн ус биш, харин ердөө л хэдэн мянган жилийн турш тогтонги байсан булингартай ус юм. Амийн усаар хангагдаагүй хүмүүс үүрд хүүр, Сатаны зугаа, тамын хүү хэвээр үлдэнэ. Ийм маягаар, тэд Бурханыг хэрхэн харж чадах вэ? Хэрвээ чи зөвхөн өнгөрсөнтэй зууралдаж, юу ч хийлгүйгээр аливаа зүйлийг байгаагаар нь байлгахыг хичээн, байгаа байдлаа өөрчилж, түүхийг хаяхаар хичээдэггүй бол үргэлж Бурханы эсрэг байхгүй гэж үү? Бурханы ажлын алхмууд нь долгилох давлагаа, нүргэлэх аянга мэт далайцтай, хүчирхэг—гэтэл чи мунхаглалдаа хөтлөгдөж, юу ч хийлгүй зүгээр суугаад сүйрлээ хүлээж байна. Ийм байж чи яаж Хурганы мөрийг дагадаг нэгэн гэж тооцогдох юм бэ? Чи өөрийнхөө зууралддаг тэр Бурханыг үргэлж шинэ, хэзээ ч хуучирдаггүй Бурхан гэж яаж батлах вэ? Мөн шарласан номуудын чинь бичиг үсэг яаж чамайг шинэ эринд аваачих вэ? Тэдгээр нь яаж чамайг Бурханы ажлын алхмуудыг хайхад хөтлөх вэ? Мөн яаж

[a] Үжирсэн мод: “ямар ч нэмэргүй” гэсэн утгатай хятад хэлц.

чамайг тэнгэр лүү аваачих вэ? Чиний гарт буй зүйл бол түр зуурын тайтгарал өгөх бичиг үсэг болохоос амь өгөх чадалтай үнэн биш юм. Чиний уншдаг бичвэрүүд зүгээр л хэл яриаг чинь баяжуулдаг зүйл болохоос төгс болгуулах зам байх нь байтугай, хүний амьдралыг мэдэхэд туслах мэргэн ухааны үг ч биш юм. Энэ зөрөө чамд ямар нэг юм бодогдуулахгүй байна уу? Энэ чамд доторх нууцуудыг нь ойлгуулахгүй байна гэж үү? Чи өөрөө тэнгэрт хүрч очиж, Бурхантай уулзаж чадах уу? Бурхан ирэхгүй бол чи өөрөө тэнгэрт хүрч очиж, Бурхантай хамт гэр бүлийн аз жаргал эдэлж чадах уу? Чи одоо ч мөрөөдсөөр л байна уу? Тэгвэл Би чамайг мөрөөдөхөө больж, одоо хэн ажиллаж байгааг, эцсийн өдрүүдэд хүмүүсийг аврах ажлыг хэн явуулж байгааг хар гэж зөвлөж байна. Эс бөгөөс чи хэзээ ч үнэнийг олж авч чадахгүй, мөн хэзээ ч амийг олж авч чадахгүй.

Христийн хэлсэн үнэнд найдалгүйгээр амь олж авахыг хүсдэг хүмүүс бол газар дэлхий дээрх хамгийн утгагүй хүмүүс, Христийн авчирсан амийн замыг хүлээн авдаггүй хүмүүс бол бүтэшгүй мөрөөдөлд автсан хүмүүс юм. Иймд Би эцсийн өдрүүдийн Христийг хүлээн авдаггүй хүмүүсийг Бурхан үүрд үзэн ядна гэж хэлдэг. Христ бол хүний эцсийн өдрүүдэд хаанчлалд орох үүд хаалга бөгөөд үүнийг хэн ч тойрч эс гарна. Христээр дамжилгүйгээр хэн ч Бурханаар төгс болгуулахгүй. Чи Бурханд итгэдэг, иймээс чи Түүний үгийг хүлээн авч, Түүний замыг дуулгавартай дагах ёстой. Чи үнэнийг ойлгохгүйгээр, амийн хангалтыг хүлээн авахгүйгээр ерөөл хүртэнэ гэж санахын ч хэрэггүй. Христэд үнэхээр итгэдэг бүх хүнийг амиар хангахын тулд Тэр эцсийн өдрүүдэд ирсэн. Энэ ажил нь хуучин эринийг төгсгөж, шинэ эринд орохын төлөө байдаг бөгөөд Түүний ажил бол шинэ эринд орох бүх хүний явах ёстой зам юм. Хэрвээ чи хүлээн зөвшөөрч чадахгүй, оронд нь яллаж, доромжилж, бүр хяхаж хавчдаг бол мөнхийн галд шатах тавилантай бөгөөд Бурханы хаанчлалд хэзээ ч орж чадахгүй. Учир нь энэ Христ бол Өөрөө Ариун Сүнсний илэрхийлэл, Бурханы илэрхийлэл, Бурханы газар дэлхий дээрх ажлаа даалгасан Нэгэн билээ. Иймд хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийн хийсэн бүхнийг хүлээн авч чадахгүй бол Ариун Сүнсийг доромжилж байна гэж Би хэлнэ. Ариун Сүнсийг доромжилдог хүмүүсийн амсах ёстой залхаан цээрлүүлэлт бүгдэд тодорхой байдаг. Хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийг эсэргүүцэж, голбол үр дагаврыг нь өмнөөс чинь үүрч чадах хэн ч байхгүй гэдгийг Би бас хэлье. Түүнчлэн энэ өдрөөс хойш Бурханы сайшаалыг хүртэх өөр боломж чамд олдохгүй; чи өөрийгөө аврахыг оролдсон ч Бурханы царайг дахин хэзээ ч харахгүй. Учир нь чиний эсэргүүцдэг зүйл хүн биш, чиний голдог зүйл ямар нэг шалихгүй хүн биш, харин Христ билээ. Чи үүний үр дагавар юу байхыг мэдэж байна уу? Чи жижиг алдаа гаргасан биш, харин асар том нүгэл үйлдсэн байх болно. Иймээс, үнэн л чамд амь авчирч, өөр юу ч биш зөвхөн үнэн л чамд дахин төрж, Бурханы царайг харах боломж олгох учраас Би бүх хүнд үнэний өөдөөс архирч, болгоомжгүй шүүмжлэл хэлэхгүй байхыг зөвлөж байна.

ХҮРЭХ ГАЗРЫНХАА ТӨЛӨӨ ХАНГАЛТТАЙ САЙН ҮЙЛ БЭЛД

Би та нарын дунд их ажил хийсэн бөгөөд мэдээж нэлээд хэдэн айлдвар ч хэлсэн. Гэсэн ч Миний үг болон ажил эцсийн өдрүүд дэх ажлын маань зорилгыг бүрэн биелүүлээгүй гэж Надад өөрийн эрхгүй санагддаг. Учир нь, эцсийн өдрүүдэд Миний ажил тодорхой нэг хүн, эсвэл тодорхой хүмүүсийн төлөө биш, харин Миний төрөлх зан чанарыг илчлэхийн төлөө байдаг. Гэсэн ч үй олон шалтгааны улмаас—магадгүй цаг хугацаа хомс юм уу ажлын завгүй хуваариас болж—хүмүүс Миний зан чанараас Миний тухай ямар ч мэдлэг олж авсангүй. Тиймээс Би, Өөрийн шинэ төлөвлөгөө, сүүлчийн ажилд орж, ажилдаа шинэ хуудас нээдэг, ингэснээр Миний оршин тогтнолоос болж Намайг хардаг бүхэн цээжээ дэлдэн, тасралтгүй цурхиран уйлна. Яагаад гэвэл, Би хүн төрөлхтний төгсгөлийг дэлхий ертөнцөд авчирдаг бөгөөд энэ мөчөөс эхлээд хүн төрөлхтний өмнө бүхий л зан чанараа ил болгодог, ийнхүү Намайг мэддэг болон мэддэггүй бүх хүн нүдээ хужирлаж, үнэхээр хүний ертөнцөд ирчихсэн, бүх зүйл үржин олширдог газар дэлхийд ирчихсэн гэдгийг минь харж болох юм. Энэ бол Миний төлөвлөгөө, хүн төрөлхтнийг бүтээснээс хойших цорын ганц “өчил” минь билээ. Та нар Миний үйл хөдөлгөөн бүрд анхаарлаа бүрэн хандуулах болтугай, учир нь Миний саваа хүн төрөлхтөнд, Намайг эсэрүүцдэг бүх хүнд дахин нэгэнтээ ойртож байна.

Тэнгэрүүдийн хамтаар Би хийх ёстой ажлаа эхэлдэг. Тиймээс Би хүмүүсийн урсгал дундуур алхаж, тэнгэр газрын хооронд шилжин явдаг ба хэн ч Миний хөдөлгөөнийг ухамсарлаж, Миний үгийг анзаардаггүй. Тиймээс Миний төлөвлөгөө саадгүй өрнөсөөр байдаг. Бүх мэдрэмж чинь маш хөшүүн болсон болохоор л та нар Миний ажлын алхмуудыг мэддэггүй. Гэхдээ та нар Миний санаа зорилгыг ухаарах өдөр гарцаагүй ирнэ. Өнөөдөр Би та нартай хамт амьдарч, хамт зовдог бөгөөд Надад хүн төрөлхтний ханддаг хандлагыг аль эрт ойлгож авсан. Би энэ талаар цааш нь ярихыг хүсдэггүй, энэхүү аягүй сэдвээр нэмж жишээ татан та нарт ичгүүр авчрахыг бүр ч хүсдэггүй. Та нар хийсэн бүхнээ зүрх сэтгэлдээ санадаг гэж л Би найддаг, ингэснээр бид дахин уулзах тэр өдөр тайлангаа тулгаж болох юм. Би та нарын дундаас хэнийг ч хилсээр буруутгахыг хүсдэггүй, учир нь Би үргэлж голч шударга, зүй зохистой, нэр төртэйгээр үйлдэж ирсэн билээ. Мэдээж, та нар ч бас уужим сэтгэлтэй байж, тэнгэр, газар юм уу өөрийнхөө мөс чанарт харшлах юу ч хийхгүй гэдэгт Би найдаж байна. Та нараас Миний шаарддаг цорын ганц зүйл бол энэ. Аймшигтай том нүгэл үйлдсэнээсээ болоод олон хүн айн түгшиж, санаа зовдог бөгөөд ганц ч удаа сайн үйл үйлдээгүйгээсээ болж олон хүн өөрсдөөсөө ичдэг. Гэсэн ч нүглээсээ ичих нь байтугай, муу байснаа улам дордож, Миний зан чанарыг туршихын тулд хараахан ил болоогүй байсан бузар дүрийг нь нуусан багаа бүрэн хуу татдаг хүмүүс ч бас олон бий. Би аливаа нэг хүний үйлдлийг тоодог ч үгүй, анхаардаг ч үгүй. Харин ч мэдээлэл цуглуулах ч бай, газар нутгаар аялах ч бай,

эсвэл Өөрийн сонирхлын дагуу ямар нэгэн зүйл хийх ч бай хамаагүй, Би Өөрийн хийх учиртай ажлыг хийдэг. Гол цаг үед Би хүмүүсийн дундах ажлаа ганц ч хором оройтолгүй, эсвэл эртдэлгүйгээр анх төлөвлөж байснаараа төвөггүй, шуурхай явуулдаг. Гэхдээ Миний ажлын алхам бүрд зарим хүн хөсөр хаягддаг, учир нь Би тэдний долигонуур занг болон хуурамч дүр эсгэдэг боол шиг дүр төрхийг жигшдэг. Миний зэвүүцдэг хүмүүс, санаатай ч бай, санаандгүй ч бай хаягдах нь гарцаагүй. Товчхондоо, Би Өөрийнхөө үзэн яддаг бүх хүнийг Өөрөөсөө хол байлгана. Миний гэрт үлдсэн хорон муу хүмүүсийг Би хэлтрүүлэхгүй гэдгийг хэлэхийн ч хэрэггүй. Хүний шийтгэлийн өдөр ойрхон байгаа учраас тэр бүх жигшүүртэй сүнсийг Өөрийн гэрээс хөөн явуулах гэж Би яардаггүй, учир нь Надад Өөрийн гэсэн төлөвлөгөө бий.

Одоо бол Би хүн бүрийн төгсгөлийг тодорхойлдог үе, харин хүнийг хүн болгож эхлэх үе шат биш. Би хүн бүрийн үг, үйлдлийг, Намайг дагасан тэдний зам, тэдний төрөлх шинж чанар болон эцэстээ тэд биеэ хэрхэн авч явсныг бүртгэлийн дэвтэртээ нэг бүрчлэн тэмдэглэдэг. Ийм маягаар, ямар ч хүн байлаа гэсэн, хэн ч Миний гараас мултрахгүй бөгөөд Миний тогтоосончлон бүгд өөрсдийн төрөлтэй хамт байх болно. Би хүний нас, зэрэг зиндаанд үндэслэж бус, туулсан зовлон шаналлын хэмжээ, ялангуяа өрөвдүүлж буй түвшинд нь үндэслэж бус, харин үнэнийг эзэмшдэг эсэхийнх нь дагуу хүн бүрийн хүрэх газрыг тодорхойлдог. Үүнээс өөр сонголт гэж үгүй. Бурханы хүслийг дагадаггүй бүх хүн ч бас шийтгүүлнэ гэдгийг та нар ухаарах ёстой. Энэ бол хэн ч өөрчилж чадахгүй зүйл юм. Тиймээс шийтгүүлдэг бүх хүн Бурханы зөвт байдлын улмаас тийнхүү шийтгүүлж, тоймгүй олон муу үйлийнхээ залхаан цээрлүүлэлтийг амсдаг юм. Би эхэлснээс нь хойш төлөвлөгөөндөө ганц ч өөрчлөлт хийгээгүй. Хүний тухайд гэх юм бол, ердөө л Миний үгээ чиглүүлдэг хүмүүсийн тоо хорогдож, үнэхээр сайшаадаг хүмүүсийн тоо ч бас хорогдож байх шиг байна. Гэхдээ Миний төлөвлөгөө хэзээ ч өөрчлөгдөөгүй гэж Би хэлсээр байна; харин ч хүний итгэл, хайр үргэлж өөрчлөгдөж, дандаа багасан, хүн бүр Надад зусардаж байснаа хүйтэн хөндий хандаж, бүр Намайг хаяхдаа хүрэх ч боломжтой. Би зэвүүцэж, үзэн ядаж, эцэст нь шийтгэл оноомоор болох хүртэл та нарт хандах Миний хандлага халуун дулаан ч биш, хүйтэн цэвдэг ч биш байх болно. Гэвч шийтгэлийн чинь өдөр Би та нарыг мөн л харна, харин та нар Намайг харж чадахаа болино. Та нарын дундах амьдрал Миний хувьд хэдийн залхмаар, сонирхолгүй болсон тул та нарын хорсолтой үгийн доромжлолоос зайлсхийж, тэвчихийн аргагүй бузар булай ааш авираас чинь холдож, та нар цаашид Намайг хуурч, эсвэл Надад хааш яаш байдлаар хандахаас зайлсхийхийн тулд өөр орчинд амьдрахаар сонгочихсон гэдгээ хэлэх нь илүүц юм. Та нарыг орхин явахаасаа өмнө Би үнэнтэй нийцдэггүй зүйл хийхийг цээрлэ гэж та нарт бас л захих ёстой. Харин ч та нар бүгдэд таалагдах, бүгдэд ашиг тус авчрах, мөн өөрийн чинь хүрэх газарт ашиг тустай зүйл хийх хэрэгтэй, эс бөгөөс гамшгийн дунд өөр хэн ч биш, чи л зовно.

Намайг хайрлаж, өөрсдийгөө орхидог хүмүүс дээр Миний өршөөл харагддаг. Харин хорон муу хүмүүст очдог шийтгэл нь яг нарийндаа Миний зөвт зан чанарын

нотолгоо, тэр ч бүү хэл, Миний уур хилэнгийн гэрчлэл юм. Гамшиг ирэх үед Намайг эсэргүүцдэг бүхэн өлсгөлөн, тахалд нэрвэгдээд цурхиран уйлна. Бүх төрлийн хорон мууг үйлдсэн боловч Намайг олон жил дагасан хүмүүс нүглийнхээ төлөөсийг төлөхөөс зайлахгүй; тэд ч бас хэдэн сая жилийн турш ховорхон үзэгдэх гамшигт унаж, байнга айж, түгшсэн байдалтай амьдарна. Надад үнэнч зангаа харуулсан дагагчид маань баярлан хөөрч, Миний сүр хүчийг шагшин магтана. Тэд үгээр хэлэхийн аргагүй сэтгэл ханамжийг мэдэрч, хүн төрөлхтөнд Миний урьд өмнө хэзээ ч хайрлаж байгаагүй баяр хөөр дунд амьдарна. Учир нь Би хүний сайн үйлийг нандигнаж, муу үйлийг нь жигшдэг билээ. Би хүн төрөлхтнийг анх залж чиглүүлж эхэлснээсээ хойш Өөртэйгөө санаа нэгтэй бүлэг хүмүүсийг олж авах гэж хүсэмжлэн найдсаар ирсэн юм. Харин Надтай адил санаатай биш хүмүүсийг Би хэзээ ч мартдаггүй; Би зүрх сэтгэлдээ тэднийг үргэлж үзэн ядаж, тэдэнд цээрлэл авчрах боломжийг хүлээдэг бөгөөд үүнийг Би баясан харна. Одоо Миний өдөр нэгэнт ирчихлээ, Би цаашид хүлээх хэрэггүй!

Миний сүүлчийн ажил хүнийг шийтгэхийн төлөө төдийгүй, мөн хүний хүрэх газрыг зохицуулахын төлөө байдаг. Түүнчлэн энэ нь бүх хүнд Миний үйл хэрэг, үйлдлийг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө байдаг. Миний хийсэн бүхэн зөв, мөн Миний хийсэн бүхэн бол Миний зан чанарын илэрхийлэл, харин хүний үйл хэрэг биш бөгөөд хүн төрөлхнийг бий болгосон нь байгаль бүр ч биш, харин бүтээлийн амьд зүйл бүрийг тэжээн тэтгэдэг нь Би юм гэдгийг хүн нэг бүрд харуулахыг Би хүсдэг. Миний оршин тогтнолгүйгээр хүн төрөлхтөн мөхөж, гай зовлонгийн дайралтад л өртөнө. Үзэсгэлэнт нар, сарыг, эсвэл ногоон дэлхийг нэг ч хүн дахин хэзээ ч харахгүй; хүн төрөлхтөн гагцхүү хүйтэн шөнө, туулахын аргагүй үхлийн харанхуйн хөндийтэй л тулгарна. Би бол хүн төрөлхтний цорын ганц аврал. Би бол хүн төрөлхтний цорын ганц найдвар, түүнчлэн Би бол бүх хүн төрөлхтний оршин тогтнол тулгуурлаж байдаг Нэгэн билээ. Надгүйгээр хүн төрөлхтөн дорхноо зогсонги байдалд орно. Надгүйгээр хүн төрөлхтөн сүйрлийн гай зовлон амсаж, төрөл бүрийн сүнсний хөлд гишгэлэгдэнэ, гэхдээ хэн ч Намайг анхаардаггүй. Би өөр хэний ч хийж чадахгүй ажлыг хийсэн бөгөөд хүн зарим нэг сайн үйлээрээ Миний ачийг хариулж чадна гэж л найддаг. Тун цөөхөн хүн Миний ачийг хариулж чадсан хэдий ч Би хүний ертөнц дэх аянаа ямар ч атугай дуусгаж, ажлынхаа дараагийн алхмыг эхлүүлнэ, учир нь энэ олон жилийн турш хүмүүсийн дунд ийш, тийш гүйсэн минь бүгд үр дүнтэй байсан бөгөөд Би тун сэтгэл хангалуун байна. Би хүмүүсийн тоог биш, харин тэдний сайн үйлийг анхаардаг. Товчхондоо, та нар өөрсдийн хүрэх газарт зориулан хангалттай сайн үйл бэлдэнэ гэж Би найддаг. Тэгвэл Би сэтгэл хангалуун болно; эс бөгөөс та нарт тохиолдох гамшгаас хэн ч зугтаж чадахгүй. Гамшиг Надаас үүдэлтэй бөгөөд мэдээж Би зохион байгуулдаг. Хэрвээ та нар Миний нүдэнд сайн харагдаж чадахгүй бол гай гамшгийн зовлон амсахаас зайлахгүй. Гай зовлонгийн дунд, та нарын үйлдэл, үйл хэрэг чинь бүхэлдээ зүй зохистой гэж тооцогдоогүй, учир нь та нарын итгэл, хайр хий хоосон бөгөөд хулчгар

юм уу хатуужилтай гэдгээ л та нар харуулсан. Энэ тухайд Би зөвхөн сайн, муу гэдгийг шүүнэ. Та нарын тус тусын бүх үйлдэл, бүх илэрхийллийг Би анхаарсаар байдаг бөгөөд үүний үндсэн дээр төгсгөлийг чинь тодорхойлно. Гэхдээ Би үүнийг тодорхой болгох ёстой: Гай зовлонгийн үеэр Надад өчүүхэн төдий ч үнэнч байгаагүй хүмүүст Би цаашид өршөөнгүй хандахгүй, учир нь Миний өршөөл ердөө энэ хүртэл үргэлжилдэг. Түүнчлэн Надаас нэгэнтээ урвасан хэнд ч Би дургүй, найз нөхдийнхөө ашиг сонирхлыг худалддаг хүмүүстэй харилцах бүр ч дургүй. Тухайн хүн хэн байх нь хамаагүй, энэ бол Миний зан чанар юм. Би та нарт үүнийг хэлэх ёстой: Миний зүрх сэтгэлийг шархлуулдаг хэн ч Надаас хоёр дахь удаагаа өршөөл хүртэхгүй бөгөөд Надад үнэнч байсаар ирсэн хэн боловч зүрх сэтгэлд минь үүрд үлдэнэ.

ЧИ ХЭНД ҮНЭНЧ ВЭ?

Яг одоо та нарын туулан амьдарч буй өдөр хоног бүр тун чухал бөгөөд энэ нь хүрэх газар, хувь заяанд чинь дээд зэргийн ач холбогдолтой, иймээс та нар өнөөдөр өөрсдөдөө байгаа бүхнийг нандигнаж, өнгөрч буй хором бүрийг эрхэмлэх ёстой. Та нар энэ амьдралдаа дэмий амьдрахгүйн тулд өөртөө хамгийн их ашиг тус хүртээхэд аль болох их цаг гаргах ёстой. Намайг яагаад ийм үг хэлж байгаа талаар та нарт хачирхалтай санагдаж байж магад. Шулуухан хэлэхэд, та нарын хэний ч үйлдэлд Би сэтгэл хангалуун байдаггүй, учир нь одоогийн байдал чинь Миний найдаж байсан зүйл биш. Тиймээс Би ингэж хэлж болно: Та нар дор бүрнээ аюулын ирмэг дээр байгаа ба тусламж гуйсан урьдын хашхираан, үнэнийг эрэлхийлж, гэрлийг эрж хайх хуучны хүсэл эрмэлзэл чинь төгсгөлдөө ойртож байна. Энэ бол эцэстээ та нарын барьж буй хариу бөгөөд Миний хэзээ ч хүлээж байгаагүй зүйл юм. Би баримтын эсрэг ярихыг хүсэхгүй, учир нь та нар Намайг ихэд гонсойлгосон. Та нар үүнийг зүгээр орхихыг хүсдэггүй, бодит байдалтай нүүр тулахыг хүсдэггүй байж магадгүй, гэсэн ч Би та нараас үүнийг нухацтай асуух ёстой: Энэ бүх жилд та нарын зүрх сэтгэл яг юугаар дүүрсэн байсан бэ? Хэнд үнэнч юм бэ? Эдгээр асуулт санамсаргүй гарсан гэж битгий хэл, мөн яагаад ийм зүйл асуусныг минь Надаас бүү асуу. Үүнийг мэдэж ав: Би та нарыг дэндүү сайн мэддэг, та нарыг дэндүү их халамжилдаг, мөн та нарын хийж байгаа бүхэнд зүрх сэтгэлээ хэтэрхий их зориулсан учраас та нараас зогсолтгүй асууж, гашуун зовлон бэрхшээл үүрсэн. Гэсэн ч та нар Надад хайхрамжгүй байдал, тэвчишгүй арга мөхөс байдлаас өөр юугаар ч хариу барьдаггүй. Та нар Надад хааш яаш хандсаар ирсэн; Би энэ талаар юу ч мэдэхгүй байх боломжтой гэж үү? Хэрвээ ингэж боддог бол та нар Надад үнэхээр сайхан сэтгэлээр ханддаггүй гэдэг баримтыг улам нотолж байна. Иймээс, та нар өөрийгөө хуурч байна гэж Би хэлдэг. Та нар бүгдээрээ яг юу хийж байгаагаа ч мэддэггүй маш ухаантай—тэгвэл Надад тайлан өгөхдөө та нар юу ашиглах вэ?

Миний санааг хамгийн их зовоодог асуулт бол та нарын зүрх сэтгэл яг хэнд үнэнч вэ гэдэг юм. Та нар дор бүрнээ бодлоо цэгцлэх гэж хичээж, хэнд үнэнч болохоо, хэний төлөө амьдардгаа өөрсдөөсөө асууна гэдэгт Би бас найддаг. Та нар иймэрхүү асуултыг хэзээ ч анхааралтай бодолцож үзээгүй байх, тэгэхээр Би та нарт хариултыг нь илчилбэл ямар вэ?

Санах ойтой хэн боловч энэ баримтыг хүлээн зөвшөөрнө: Хүн өөрийнхөө төлөө амьдардаг ба өөртөө үнэнч байдаг. Та нарын хариулт бүхэлдээ зөв гэж Би бодохгүй байна, учир нь та нар тус тусын амьдралдаа оршиж, дор бүрнээ өөрийн зовлонтой тэмцэлдэж байгаа. Ийм болохоор та нар хайртай хүмүүстээ, мөн таалагддаг зүйлсдээ үнэнч; өөрсдөдөө бүрэн дүүрэн үнэнч биш. Та нар дор бүрнээ эргэн тойрныхоо хүмүүс, үйл явдал, эд юмсын нөлөөнд автдаг учраас өөрсдөдөө үнэхээр үнэнч биш байдаг. Өөрсдөдөө үнэнч байгааг чинь сайшаах гэж биш, харин ямар нэг зүйлд үнэнч байдгийг чинь илчлэх гэж Би эдгээр үгийг хэлдэг, учир нь маш олон жилийн турш Би та нарын хэнээс ч, хэзээ ч үнэнч байдлыг хүлээж аваагүй. Та нар Намайг энэ олон жил дагасан атлаа үнэнч байдлынхаа өчүүхэн төдийг ч Надад өгөөгүй. Харин ч хайртай хүмүүс болон таалагддаг зүйлсээ тойрон эргэлдэж, бүр цаг үргэлж, хаашаа ч явсан тэдгээрийг зүрх сэтгэлдээ ойр байлгадаг ба хэзээ ч хаяж орхиогүй. Та нар хайрладаг ямар нэг зүйлээ хүсэмжилж, тэмүүлэх тоолонд энэ нь Намайг дагаж байхад, эсвэл бүр Миний үгийг сонсож байхад чинь хүртэл тохиолддог. Тиймээс та нараас Миний шаарддаг үнэнч байдлыг та нар харин өөрсдийн “тэжээвэр амьтдад” үнэнч байж, тэднийг нандигнахад ашигладаг гэж Би хэлнэ. Хэдийгээр та нар Миний төлөө ганц, хоёр юм золиосолж байсан ч энэ нь та нарын бүх юмыг төлөөлдөггүй, Надад үнэхээр үнэнч байдаг гэдгийг чинь харуулдаггүй. Та нар дурладаг ажил үйлдээ өөрсдийгөө татан оролцуулдаг: Зарим хүн хөвгүүд, охиддоо, бусад нь нөхөр, эхнэр, эд баялаг, ажил, дарга нар, байр суурь, эмэгтэйчүүдэд үнэнч байдаг. Үнэнч байдаг зүйлээсээ та нар хэзээ ч залхаж, дургүйцдэггүй; харин ч эдгээр зүйлийг илүү их хэмжээгээр, илүү сайн чанартайг нь эзэмшихээр улам бүр тэмүүлдэг ба хэзээ ч орхидоггүй. Намайг болон Миний үгийг та нар үргэлж дуртай зүйлсийнхээ хойгуур түлхдэг. Тэгээд тэдгээрийг хамгийн сүүлд эрэмбэлэхээс өөр арга та нарт байдаггүй. Хараахан олж мэдээгүй байгаа зүйлсдээ үнэнч байх гэж энэ сүүлчийн байрыг үлдээдэг хүмүүс ч бий. Тэдний зүрх сэтгэлд Миний өчүүхэн ч ул мөр хэзээ ч байгаагүй. Намайг та нараас хатуу чанд шаардаж, эсвэл хилсээр буруутгаж байна гэж та нар бодож байж магад—гэхдээ гэрийнхэнтэйгээ хамт цагийг жаргалтай өнгөрүүлж байхдаа та нар Надад нэг ч удаа үнэнч байгаагүй гэдэг баримтыг ер нь бодолцож үзсэн үү? Иймэрхүү үед та нар үүнээс болж шаналдаггүй гэж үү? Зүрх сэтгэл чинь баяр хөөрөөр дүүрч, ажил хөдөлмөрийнхөө төлөө шагнал хүртэх үедээ өөрсдийгөө хангалттай үнэнээр зэвсэглээгүйдээ гутардаггүй гэж үү? Миний сайшаалыг хүртээгүйнхээ төлөө та нар хэзээ цурхиран уйлсан бэ? Та нар хөвгүүд, охидынхоо төлөө тархиа гашилгаж, сэтгэлээ асар их чилээдэг ч мөн л сэтгэл ханадаггүй; тэдний өмнөөс мэрийгээгүй,

тэдний төлөө чадах бүхнээ хийгээгүй гэж бодсоор байдаг. Харин Надад та нар үргэлж тоомсоргүй, хааш яаш хандаж ирсэн; Би дурсамжид чинь л байдаг боловч зүрх сэтгэлд чинь удаан үлддэггүй. Та нарын төлөөх Миний чин сэтгэлийн хүчин чармайлтыг та нар ерөөсөө мэдэрдэггүй бөгөөд тэдгээрийг хэзээ ч ойлгож байгаагүй. Та нар ердөө товчхон эргэцүүлээд, энэ нь хангалттай гэж боддог. Ийм "үнэнч байдал" бол Миний эртнээс хүсэн мөрөөдсөн зүйл биш, харин эртнээс жигшсэн зүйл билээ. Гэхдээ Намайг юу ч гэж хэлсэн бай, та нар ганц хоёрхон зүйлийг л зөвшөөрсөөр байдаг; үүнийг бүрэн хүлээн зөвшөөрч чаддаггүй, учир нь та нар бүгд "өөртөө маш итгэлтэй" бөгөөд Миний хэлсэн үгээс алийг нь хүлээн зөвшөөрөхөө үргэлж шилж, сонгодог. Хэрвээ та нар өнөөдөр ийм хэвээр байх юм бол та нарын өөртөө итгэлтэй байдалтай харьцах зарим арга Надад бий, мөн үүнээс гадна Миний бүх үг үнэн бөгөөд тэдгээрийн аль нь ч баримтуудыг гуйвуулдаггүй гэдгийг Би та нараар хүлээн зөвшөөрүүлнэ.

Хэрвээ Би яг одоо та нарын өмнө хэсэг мөнгө тавиад, дураараа сонгох эрх өгсөн бол, сонголтын чинь төлөө та нарыг яллахгүй байсан бол—та нарын ихэнх нь мөнгийг сонгож, үнэнийг хаях байсан. Та нарын дундаас арай өөдтэй нь мөнгийг орхиж, үнэнийг дурамжхан сонгож байхад энэ хоёрын дундах хүмүүс нэг гартаа мөнгө, нөгөөдөө үнэнийг барих байсан. Ийнхүү та нарын үнэн төрх илэрхий болохгүй гэж үү? Үнэн болон үнэнч байдаг зүйлийнхээ аль нэгийг сонгох үедээ та нар бүгд ийм сонголтыг хийх бөгөөд хандлага чинь хэвээр үлдэх байсан. Тэгэхгүй гэж үү? Зөв, буруугийн хооронд хэлбэлзсэн хүмүүс та нарын дунд олон байдаггүй гэж үү? Гэр бүл ба Бурхан, хүүхдүүд ба Бурхан, эв найр ба хагарал, элбэг баян байдал ба ядуурал, байр суурь ба эгэл байдал, дэмжлэг авах ба хөсөр хаягдах зэрэг эерэг ба сөрөг, хар ба цагааны хоорондох тэмцэлд хийсэн сонголтуудаа та нар мэдэж байгаа нь лавтай. Эв найртай гэр бүл, салсан гэр бүл хоёроос та нар эхнийхийг нь сонгосон ба ингэхдээ огт эргэлзээгүй; эд баялаг, үүрэг хоёроос бас л эхнийхийг нь, бүр эрэг рүү буцах[a] хүсэлгүйгээр сонгосон; тансаг байдал, ядуурал хоёроос та нар эхнийхийг нь сонгосон; өөрийнхөө хөвгүүд охид, эхнэр, нөхөр болон Миний дундаас та нар эхнийхийг нь сонгосон; үзэл, үнэн хоёроос дахиад л эхнийхийг нь сонгосон. Бүх төрлийн ёрын муу үйл хэрэгтэй чинь тулгараад Би та нарт итгэх итгэлээ бараг алдчихсан. Зүрх сэтгэл чинь зөөлрөхөөргүй маш хатуу байдаг нь Намайг эгээ л туйлын их гайхшируулдаг. Олон жилийн зүтгэл, хүчин чармайлт Надад, та нарын орхилт, цөхрөлөөс өөр юу ч авчраагүй бололтой, гэвч та нарт тавих найдлага маань өдөр ирэх бүр ихэсдэг, учир нь Миний өдөр хүн бүрийн өмнө бүрэн ил болсон билээ. Гэсэн ч та нар харанхуй, ёрын муу зүйлсийг цөхрөлтгүй эрж хайн, тэдгээрээс зууралдахаа болихоос татгалздаг. Тэгвэл та нарын төгсгөл ямар байх вэ? Та нар үүнийг ер нь анхааралтай бодож үзсэн үү? Хэрвээ та нараас дахиад сонголт хийхийг хүсвэл хандлага чинь ямар байх вэ? Мөн

[a] Эрэг рүү буцах: "муу замаасаа буцах" гэсэн утгатай хятад хэлц үг.

л эхнийх нь байх уу? Та нар бас л Миний урмыг хугалж, таагүй уй гашуу авчрах болов уу? Та нарын зүрх сэтгэл мөн л өчүүхэн төдий халуун дулаан хэвээр байх болов уу? Миний зүрх сэтгэлийг тайвшруулахын тулд юу хийхээ мэдэхгүй хэвээр байх болов уу? Энэ мөчид та нар юу сонгож байна вэ? Миний үгэнд захирагдах уу, эсвэл тэдгээрээс залхах уу? Миний өдөр яг нүдний чинь өмнө ил болсон бөгөөд та нарт тулгардаг зүйл бол шинэ амьдрал, шинэ эхлэлийн цэг юм. Гэхдээ энэхүү эхлэлийн цэг нь урьдын шинэ ажлын эхлэл биш, харин хуучин ажлын төгсгөл юм гэдгийг Би та нарт хэлэх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ нь төгсгөл үе билээ. Энэхүү эхлэлийн цэгийн юу нь ер бусын болохыг та нар бүгд ойлгож чадна гэж Би бодож байна. Гэхдээ удалгүй нэг л өдөр та нар энэ эхлэлийн цэгийн жинхэнэ утга учрыг ойлгоно, тэгвэл бид хамтдаа энэхүү эхлэлийн цэгийг өнгөрөөж, ирж буй төгсгөлийг угтацгаая! Харин шударга бус болон шударга байдалтай тулгарах үедээ та нар үргэлж эхнийхийг сонгодог нь Миний санааг зовоосоор байгаа юм. Гэхдээ энэ нь бүгд та нарын урьдын явдал. Би ч гэсэн та нарын өнгөрсөн бүхнийг мартана гэдэгтээ найдаж байна, гэвч мартахад тун хэцүү байдаг. Гэсэн ч Надад үүнийг хийх тун сайн арга бий: Өнгөрснийг ирээдүй орлож, урьдын сүүдэр чинь өнөөдрийн жинхэнэ төрхөөр чинь солигдон замхраг. Тиймээс Би дахин нэг удаа сонголт хийлгэн та нарт төвөг удах ёстой: Та нар яг хэнд үнэнч юм бэ?

ХҮРЭХ ГАЗРЫН ТУХАЙ

Хүрэх газрыг дурдах бүрд та нар тун нухацтай ханддаг; түүнчлэн энэ нь та бүгдийн онцгой мэдрэмтгий байдаг зүйл юм. Зарим хүн сайхан хүрэх газар олж авахын тулд толгойгоороо газар мөргөж, Бурханы өмнө бөхөлзөхөөр тэсэн яддаг. Үгээр илэрхийлэх шаардлагагүй та нарын эрмэлзлийг Би ялган таньж чадна. Та нар махан биеэ гамшигт унагахыг хүсдэггүй, ирээдүйд үүрдийн шийтгэлд унахыг бүр ч хүсдэггүй. Та нар арай илүү эрх чөлөөтэй, арай амар хялбар амьдрахыг л хүсдэг. Тиймээс, хүрэх газрын тухай дурдах бүрд тун их түгшиж, анхаарал хандуулаагүйгээсээ болж Бурханд халдаад, зохих цээрлүүлэлтээ хүлээх вий гэхээс ихэд айдаг. Та нар хүрэх газрынхаа төлөө буулт хийхээс татгалзаагүй бөгөөд нэгэн цагт залирхаг, хөнгөмсөг явсан олон хүн гэнэт маш эелдэг, чин үнэнч болчихсон; үнэнч байгаа чинь хүмүүсийг голд нь ортол дааруулдаг. Гэсэн ч та нар бүгд “үнэнч” зүрх сэтгэлтэй бөгөөд гомдол, хууран мэхлэлт, үнэнч байдал гээд сэтгэл дэх нууцаа юу ч нуулгүйгээр Надад байнга уудалсан. Ерөнхийдөө, та нар өөрсдийнхөө оршихуйн хамгийн гүнд орших мөн чанарын зүйлсийг Надад тун илэн далангүй “улайсан”. Мэдээж, эдгээр нь Надад дэндүү танил болсон учраас Би ийм зүйлээс хэзээ ч зайлсхийж байгаагүй. Та нар Бурханы сайшаалыг хүртэхийн тулд ганц үсээ алдсанаас эцсийн хүрэх газрынхаа төлөө их гал руу орохыг илүүд үзнэ. Би та нарт хэтэрхий ягшмал хандаж байгаа юм биш; харин Миний хийдэг бүхэнтэй нүүр

тулахдаа та нар чин үнэнч зүрх сэтгэлгүй байгаа юм. Та нар дөнгөж сая хэлснийг минь ойлгохгүй байж магадгүй тул Би та нарт энгийнээр тайлбарлая: Та нарт хэрэгтэй зүйл үнэн ба амь биш, биеэ хэрхэн авч явах тухай зарчим ч биш, Миний уйгагүй ажил бүр ч биш. Харин ч та нарт хэрэгтэй зүйл бол эд баялаг, байр суурь, гэр бүл, гэрлэлт зэрэг махан биеэрээ эзэмшдэг бүхэн чинь билээ. Та нар Миний үг болон ажлыг бүрмөсөн үл хэрэгсдэг тул та нарын итгэлийг хайнга гэсэн нэг үгээр дүгнэж болно. Та нар зорьсон зүйлээ биелүүлэхийн тулд юуг ч хийнэ, гэхдээ Бурханд итгэх итгэлтэй холбоотой асуудлуудын төлөө тэгэхгүй гэдгийг чинь Би олж мэдсэн. Харин ч та нар харьцангуй үнэнч, бас харьцангуй нухацтай байдаг. Тийм учраас Би, зүрх сэтгэл нь туйлын үнэнч бус хүмүүс Бурханд итгэх итгэлдээ бүтэлгүйтдэг гэж хэлдэг. Сайтар бод—та нарын дунд бүтэлгүй хүн олон байна уу?

Хүмүүс өөрсдийнхөө үйлдлээс үүдэн Бурханд итгэх итгэлдээ амжилтад хүрдэг гэдгийг та нар мэдэх учиртай; хүмүүс амжилтад хүрэхийн оронд бүтэлгүйтэх үед тэр нь ч бас өөр бусад хүчин зүйлийн нөлөөнөөс бус, өөрсдийнх нь үйлдлээс болдог. Та нар Бурханд итгэхээс илүү хэцүү, илүү их зовлон учруулах зүйлд хүрэхийн тулд юуг ч хийн, үүнд тун нухацтай хандаж, бүр ямар ч алдаа гаргахыг хүсэхгүй байх байсан гэдэгт Би итгэдэг; энэ бол амьдралдаа та нарын гаргадаг нөр их хичээл чармайлт юм. Та нар гэр бүлийнхээ нэг ч гишүүнийг мэхлэхгүй байх нөхцөл байдалд Миний махбодыг мэхлэх чадвартай. Энэ бол та нарын тууштай зан авир, амьдралын чинь зарчим билээ. Хүрэх газар чинь гойд сайхан, хүссэнээр чинь байг гэсэндээ та нар хүрэх газрынхаа төлөө Намайг мэхлэхээр хуурамч царай гаргасаар л байгаа бус уу? Та нарын үнэнч зан түр зуурынх, чин сэтгэл чинь ч ердөө түр зуурынх гэдгийг Би мэднэ. Та нарын шийдвэр, төлж байгаа төлөөс ирээдүйн төлөө биш, зөвхөн өнөөдрийн төлөө байдаг бус уу? Та нар наймаа хийх цор ганц зорилготойгоор үзэсгэлэнтэй сайхан хүрэх газрыг олж авахаар мэрийн, эцсийн ганц хүчин чармайлт гаргахыг л хүсдэг. Та нар үнэнд өртэй болохоос зайлсхийхийн тулд, бүр Миний төлсөн төлөөсийг хариулахын тулд ч тийм хүчин чармайлт гаргадаггүй. Товчхондоо та нар хүссэн зүйлээ авахын тулд ухаалаг заль мэх ашиглахыг л хүсдэг боловч үүнийхээ төлөө ил тод тэмцэхийг хүсдэггүй. Энэ нь та нарын чин хүсэл биш гэж үү? Та нар дүр эсгэх ёсгүй, мөн нойр хоолноос гартлаа хүрэх газрынхаа төлөө тархиа гашилгах ч ёсгүй. Эцэст нь, та нарын төгсгөл аль хэдийн тодорхойлогдсон байх болно гэдэг нь үнэн бус уу? Та нар дор бүрнээ нээлттэй, үнэнч зүрх сэтгэлээр өөрсдийнхөө үүргийг чадлынхаа хэрээр биелүүлж, ямар ч төлөөс төлөхөд бэлэн байх ёстой. Та нарын хэлснээр, тэр өдөр ирэхэд Өөрийнх нь төлөө зовж, төлөөс төлсөн хэнд ч Бурхан хайхрамжгүй хандахгүй. Ийм итгэл үнэмшлийг байнга баримталбаас зохистой бөгөөд хэзээ ч мартах ёсгүй. Ийм маягаар л Би та нарын тухайд сэтгэл амар байж чадна. Эс бөгөөс, Би та нарын тухайд хэзээ ч сэтгэл амар байж чадахгүй бөгөөд та нар үүрд Миний зэвүүцлийн бай байх болно. Хэрвээ та нар бүгд мөс чанараа дагаж, бүх зүйлээ Надад зориулж, Миний ажлын төлөө хүчин чармайлтаа хайрлалгүй, насан туршийн эрч хүчээ

Миний сайн мэдээний ажилд зориулж чадвал та нарын ачаар зүрх сэтгэл минь баярлан догдлохгүй гэж үү? Ийм маягаар Би та нарын тухайд бүрмөсөн санаа амар байж чадна, тийм биз дээ? Та нар Миний хүлээдэг зүйлийн өрөвдмөөр өчүүхэн хэсгийг л хийж чаддаг нь харамсалтай. Ийм байхад та наритгэж найдаж байгаа зүйлээ Надаас олж авахаар оролдох бүдүүн зүрхтэй байж яаж чадаж байна вэ?

Хүрэх газар, хувь заяа чинь та нарт маш чухал—асар их ач холбогдолтой. Аливааг маш анхааралтай хийхгүй бол хүрэх газаргүй болж, хувь заяагаа сүйрүүлсэн байх болно гэж та нар итгэдэг. Гэхдээ, гагцхүү хүрэх газрынхаа төлөө хүчин чармайлтаа зарцуулдаг хүмүүс хий дэмий хөдөлмөрлөж байгаа хэрэг гэж та нар ер нь бодож байв уу? Ийм хүчин чармайлт жинхэнэ биш—худал хуурмаг, ов мэх юм. Хэрвээ тийм бол, хүрэх газрынхаа төлөө л ажилладаг хүмүүс эцсийн ялагдлынхаа ирмэгт байна, учир нь хүний Бурханд итгэх итгэл ов мэхээс болж бүтэлгүйтдэг билээ. Надад зусардах, долигонох юм уу Надад урам зоригтой хандахад дургүй гэдгээ Би урьд нь хэлсэн. Үнэнч хүмүүс Миний үнэн болон хүлээлттэй нүүр тулахад Би дуртай. Хүмүүс Миний зүрх сэтгэлийг туйлын их анхаарч, хайхарч байгаагаа харуулахад, мөн Миний төлөө бүхнийг орхиж ч чадах үед Би бүр их дуртай. Ийм маягаар л Миний зүрх сэтгэлийг тайтгаруулж болно. Яг одоо та нарт Миний дургүй зүйл хэд байна вэ? Миний дуртай зүйл хэд байна вэ? Хүрэх газрынхаа төлөө гаргасан ой гутам байдлынхаа бүхий л илрэлийг та нарын нэг нь ч ухаараагүй юм гэж үү?

Зүрх сэтгэлдээ Би, эерэг агаад дээш тэмүүлдэг аливаа сэтгэлийг шархлуулахыг хүсдэггүй, үүргээ чин үнэнчээр биелүүлж байгаа хэн нэгний эрч хүчийг сулруулахыг бүр ч хүсдэггүй. Гэсэн хэдий ч, та нарын хангалтгүй байдал, зүрх сэтгэлийн чинь гүнд оршдог бузар сүнсийг дор бүрд чинь Би сануулах учиртай. Та нар Миний үгтэй нүүр тулахдаа чин сэтгэлээ зориулж чадна гэж найдан Би үүнийг хийдэг, учир нь Надад хандах хүмүүсийн ов мэхийг Би хамгийн их үзэн яддаг билээ. Миний ажлын сүүлийн үе шатанд та нар үүргээ гойд сайн биелүүлж чадах ба хайнга хандахаа болиод үнэн сэтгэлээсээ өөрсдийгөө зориулна гэж л Би найддаг. Мэдээж, та нар бүгд сайхан хүрэх газартай байна гэж ч найддаг. Гэсэн хэдий ч, Надад цорын ганц, эцсийн үнэнч байдлаа өргөх хамгийн сайн шийдвэрийг та нараар гаргуулах Өөрийн гэсэн шаардлага Надад байсаар байгаа. Хэрвээ хүнд тийм цорын ганц үнэнч байдал байхгүй бол тэр хүн мэдээж Сатаны нандин эзэмшил бөгөөд Би түүнийг ашиглана гэж хадгалахаа болиод, харин эцэг эхээр нь асруулахаар гэр лүү нь явуулна. Миний ажил та нарт маш их ач тустай; Би та нараас үнэнч, өөдөө тэмүүлдэг зүрх сэтгэлийг л авна гэж найддаг ч одоог хүртэл Би гар хоосон байсаар байна. Энэ тухай бодоод үз: Нэг өдөр Би мөн л үгээр хэлэхийн аргагүй их гомдвол та нарт хандах хандлага минь тэр үед ямар байх вэ? Би одоогийнх шигээ эелдэг байх уу? Миний зүрх сэтгэл тэр үед одоогийнх шигээ амар амгалан байх уу? Тариалангийн талбайгаа уйгагүй хагалчхаад ганц ч үр тариа хурааж чадаагүй хүний мэдрэмжийг та нар ойлгож байна уу? Хүнд цохилтод орох үедээ хүний зүрх сэтгэл хэчнээн их шархалдгийг ойлгож байна уу? Нэгэн цагт итгэл найдвараар тун

дүүрэн байсан ч хэн нэгэнтэй муудалцан салах ёстой болсон хүний гашуун зовлонг та нар амсаж чадах уу? Уур нь хүрсэн хүний гаргасан уур хилэнг та нар харж байсан уу? Дайсагнал амсаж, хууртагдаж байсан хүний өс хонзонгоо авах эрмэлзэл ямар байдгийг та нар мэдэх үү? Хэрвээ та нар энэ хүмүүсийн сэтгэхүйг ойлгож байвал залхаан цээрлүүлэлтийнхээ үеэр Бурхан ямар хандлагатай байхыг төвөггүй ойлгоно гэж Би бодож байна! Эцэст нь, та нар бүгд хүрэх газрынхаа төлөө нухацтай хичээл чармайлт гаргана гэж Би найдаж байна, гэхдээ хичээл чармайлтдаа овжин арга ашиглахгүй байсан чинь дээр, эс бөгөөс Би зүрх сэтгэлдээ та нарт урам хугарсан хэвээр байх болно. Тэгвэл энэ урам хугарсан байдал юунд хүргэх вэ? Та нар өөрсдийгөө хуурч байгаа бус уу? Хүрэх газрынхаа тухай боддог атлаа үүнийгээ сүйтгэдэг хүмүүс бол хамгийн аврагдах боломжгүй хүмүүс юм. Ийм хүн уурлаж, унтууцсан ч гэсэн хэн түүнийг өрөвдөх билээ? Товчхондоо, Би та нарыг тохиромжтой, бас сайн хүрэх газартай байгаасай гэж хүссэн хэвээр байгаа бөгөөд үүнээс ч илүүтэйгээр, та нарын нэг нь ч гамшигт унахгүй гэж найдаж байна.

ГУРВАН САНУУЛГА

Бурханд итгэгчийн хувиар чи бүх зүйл дээр ганцхан Түүнд үнэнч байх ёстой ба бүх зүйл дээр Түүний хүсэлд нийцэж чаддаг байх ёстой. Гэвч, хэдийгээр хүн бүр энэ сургаалыг ойлгодог боловч хүний элдэв төрлийн бэрхшээлээс болоод—жишээ нь, мэдлэггүй байдал, мунхаглал, завхралаас нь болоод эдгээр хамгийн илэрхий, хамгийн үндсэн үнэн хүнээс бүрэн харагддаггүй тул төгсгөлийг чинь шийдэхээсээ өмнө Би та нарын хувьд хамгийн чухал хэдэн зүйлийг эхлээд хэлж өгөх учиртай. Намайг үргэлжлүүлэхээс өмнө та нар эхлээд үүнийг ойлгох ёстой: Миний хэлдэг үг бол бүх хүн төрөлхтөнд чиглэсэн үнэн юм; тэдгээрийг тодорхой нэгэн хүнд юм уу нэг төрлийн хүнд л хандаж хэлдэг юм биш. Тиймээс та нар Миний үгийг үнэний өнцгөөс хүлээн авахад анхаарлаа төвлөрүүлж, бүрэн анхаарсан, чин сэтгэлийн хандлагатай байх ёстой; Миний хэлдэг ганц ч үг юм уу үнэнийг бүү үл ойшоо, Миний хэлдэг бүх үгэнд хөнгөн хуумгай бүү ханд. Та нар амьдралдаа үнэнтэй хамаагүй зүйл ихээхэн хийснийг Би хардаг тул үнэний зарц болж, хорлонт муу, муухай байдалд боолчлогдохгүй байж, үнэнийг гишгэлэхгүй, Бурханы гэрийн аль ч булан тохойг бузарлахгүй байхыг онцгойлон хүсэж байна. Энэ бол та нарт өгөх Миний сануулга юм. Одоо Би уг сэдвийн талаар ярья.

Нэгдүгээрт, та нар өөрсдийнхөө хувь заяаны төлөө Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхөөр зорих ёстой. Өөрөөр хэлбэл, нэгэнт та нар Бурханы гэрийн гишүүн гэж тоологдсон гэдгээ хүлээн зөвшөөрсөн тул бүх зүйл дээр Бурханд сэтгэл санааны тайвшрал авчирч, Түүнийг хангалуун байлгах учиртай. Өөрөөр хэлбэл, чи үйлдлүүддээ зарчимтай байж, үнэнд нийцэх ёстой. Хэрвээ ингэж чадахгүй бол Бурханаар жигшигдэн, гологдож, хүн бүрд үл тоогдоно. Ийм таагүй байдалд

ормогцоо чи Бурханы гэрийн гишүүн гэж тоологдож чадахгүй. Бурханаар хүлээн зөвшөөрөгдөхгүй байх гэдэг нь энэ юм.

Хоёрдугаарт, Бурхан үнэнч хүнд дуртай гэдгийг та нар мэдэх учиртай. Бурхан итгэмжит мөн чанартай болохоор Түүний үгэнд үргэлж итгэж болно; түүнчлэн, Түүний үйлдэл алдаа мадаггүй агаад маргаангүй байдаг. Ийм учраас Өөрт нь туйлын үнэнч хүмүүст Бурхан дуртай. Үнэнч байдал гэдэг нь Бурханд зүрх сэтгэлээ өгөх, бүх зүйл дээр Бурханд үнэн сэтгэлээсээ хандаж, бүх зүйл дээр Түүнтэй илэн далангүй байж, бодит баримтыг хэзээ ч нуухгүй байж, дээд, доод хүмүүсээ мэхлэхээр оролдохгүй байж, Бурханд бялдуучлах зүйл хэзээ ч хийхгүй байна гэсэн үг юм. Товчхондоо үнэнч байна гэдэг нь өөрийн үйлдэл болон үгийг цэвэр байлгаж, Бурханыг ч, хүнийг ч мэхлэхгүй байх явдал билээ. Миний хэлдэг зүйл маш энгийн боловч та бүхний хувьд хоёр дахин хэцүү бэрх байдаг. Олон хүн үнэнч шударгаар ярьж, үйлдсэний оронд тамд яллагдахыг илүүд үздэг. Иймээс үнэнч бус хүмүүст өөрөөр ханддагт минь гайхах юмгүй. Мэдээж үнэнч байхад хэчнээн хэцүү байдгийг чинь Би сайн мэднэ. Та нар бүгд маш ухаантай, юмыг өөрсдийн өчүүхэн жаахан хэмжүүрээр хэмжихдээ дадамгай учраас Миний ажлыг хавьгүй илүү амархан болгодог. Та нар дор бүрнээ өөрсдийн нууцыг дотроо хадгалж байдаг тул Би та нарыг галаар “хүмүүжүүлэхийн” тулд нэг нэгээр чинь гай гамшигт оруулна, ингэснээр тэр цагаас хойш та нар Миний үгэнд бүрэн итгэлтэй болж магад юм. Эцэст нь Би “Бурхан бол итгэмжит Бурхан” гэх үгийг амнаас чинь гарган авна, тэгэхэд та нар цээжээ дэлдэн “Хүний зүрх сэтгэл зальтай юм!” хэмээн халаглана. Тэр үед та нарын сэтгэл санааны байдал ямар байх вэ? Та нар одоогийнх шигээ бардам байхгүй гэж Би төсөөлж байна. Тэр ч бүү хэл, одоогийнх шигээ “гүн гүнзгий, ойлгомжгүй” байхгүй. Зарим хүн Бурханы өмнө ёсорхуу, зүй зохистой байж, “хүмүүжилтэй” байхаар хүч чадлаа дайчилдаг ч Сүнсний өмнө хамаг эрээ цээрээ алддаг. Та нар ийм хүмүүсийг үнэнч хүмүүсийн тоонд оруулах уу? Хэрвээ чи хоёр нүүртэй, мөн “хүн хоорондын харилцаанд” чадварлаг бол Би чамайг гарцаагүй Бурханаар даажигнадаг хүн гэж хэлнэ. Хэрвээ үг чинь шалтаг болон хэрэггүй зөвтгөлөөр дүүрэн бол Би чамайг үнэнийг хэрэгжүүлэх дургүй хүн гэж хэлнэ. Хэрвээ чамд хуваалцахыг хүсдэггүй олон нууц байдаг бол, хэрвээ чи өөрийнхөө нууцыг буюу өөрийнхөө бэрхшээлийг бусдын өмнө дэлгэж, гэрлийн замыг эрж хайх маш дургүй бол чи авралыг амархан хүртэж, харанхуйгаас хялбархан гарч ирж чадахгүй хүн юм гэж Би хэлнэ. Хэрвээ үнэний замыг эрж хайх нь чамд тун таалагддаг бол чи үргэлж гэрэлд амьдардаг хүн юм. Хэрвээ чи Бурханы гэрт үйлчлэл үзүүлэхдээ тун их баяртай байж, нэрд гаралгүйгээр хичээнгүйлэн, чин сэтгэлээсээ ажиллаж, үргэлж өгч, хэзээ ч авдаггүй бол Би чамайг үнэнч ариун хүн гэж хэлнэ, учир нь чи шагнал эрэлхийлдэггүй, зүгээр л үнэнч шударга хүн байдаг. Хэрвээ чи илэн далангүй байхыг хүсдэг бол, байгаа бүхнээ зарлагадахыг хүсдэг бол, Бурханы төлөө амиа золиосолж, гэрчлэлдээ бат зогсож чаддаг бол, мөн Бурханыг хангалуун байлгахыг л мэддэг, өөрийгөө боддоггүй, өөрийнхөө төлөө юм авдаггүй байх

хэмжээнд үнэнч шударга бол ийм хүмүүс гэрлээр тэтгэгддэг, хаанчлалд үүрд амьдрах хүмүүс юм гэж Би хэлнэ. Чиний дотор жинхэнэ итгэл, жинхэнэ үнэнч зан байгаа эсэхийг, Бурханы төлөө зовсон баримт чамд байгаа эсэхийг болон Бурханд бүрэн захирагдсан эсэхээ чи мэдэх ёстой. Хэрвээ чамд эдгээр зүйл байдаггүй бол чиний дотор дуулгаваргүй байдал, заль мэх, шунал, гомдол үлдсэн байдаг. Зүрх сэтгэл чинь огт үнэнч шударга биш учраас чи Бурханд хэзээ ч эрэгээр хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд хэзээ ч гэрэлд амьдраагүй. Хүний хувь заяа эцэстээ яах нь түүнд үнэнч шударга, халуун сэтгэл байгаа эсэхээс болон цэвэр ариун сүнс байгаа эсэхээс хамаардаг. Хэрвээ чи маш үнэнч бус, хорлонт сэтгэлтэй, бохир сүнстэй хүн бол хувь заяаны чинь бүртгэлд бичигдсэнээр хүнийг шийтгэдэг газар очиж таарах нь гарцаагүй. Чи өөрийгөө маш үнэнч шударга гэж хэлдэг атлаа үнэний дагуу үйлдэж, үнэн үг хэлж хэзээ ч амждаггүй бол Бурхан чамайг шагнахыг хүлээсээр л байна уу? Бурхан чамайг Өөрийнхөө нүдний цэцгий мэт үзнэ гэж найдсаар л байна уу? Ийм бодол утгагүй бус уу? Чи бүх зүйл дээр Бурханыг мэхэлдэг; тэгвэл чам шиг бохир гартай хүнийг яаж Бурханы гэрт байлгаж болох юм бэ?

Та нарт Миний хэлэхийг хүсдэг гурав дахь зүйл бол энэ: Бурханд итгэн амьдрах явцдаа хүн бүр Бурханыг эсэргүүцэж, хууран мэхэлдэг зүйл хийсэн. Зарим алдаа эндлийг зөрчил гэж тооцох хэрэггүй боловч зарим нь уучилшгүй байдаг; учир нь захиргааны зарлигийг зөрчдөг буюу Бурханы зан чанарт халддаг олон үйл хэрэг бий. Өөрийнхөө хувь заяанд санаа тавьдаг олон хүн эдгээр үйл хэрэг нь юу болохыг асууж магадгүй. Та нар угаасаа биеэ тоосон, ихэрхүү бөгөөд баримтад захирагдахыг хүсдэггүй гэдгээ мэдэх ёстой. Ийм учраас өөрсдийгөө эргэцүүлсний чинь дараа Би та нарт бага багаар хэлэх болно. Захиргааны зарлигуудын агуулгыг илүү сайн ойлгож, Бурханы зан чанарыг мэдэхэд хичээл чармайлт гарга гэж Би та нарт захидаг. Эс бөгөөс амаа хамхиж, ойворгон сүржин яриаг амныхаа зоргоор чалчихгүй байх нь та нарт хэцүү санагдах бөгөөд өөрийн мэдэлгүй Бурханы зан чанарт халдаж, харанхуйд унан, Ариун Сүнсийг дэргэдээсээ алдаж, гэрлийг алдана. Та нар үйлдэлдээ зарчимгүй байж, хэлэх ёсгүй юм хэлж, хийх ёсгүй зүйл хийдэг бол тохирох залхаан цээрлүүлэлтийг хүртэнэ. Хэдийгээр чи үг болон үйлдэлдээ зарчимгүй байдаг ч Бурхан аль алинд нь тун зарчимтай байдгийг мэдэх ёстой. Залхаан цээрлүүлэлт хүртэж байгаа чинь хүнд бус, Бурханд халдсанаас чинь болдог. Хэрвээ чи амьдралдаа Бурханы зан чанарын эсрэг олон зөрчил үйлдсэн бол тамын хүүхэд болох нь дамжиггүй. Хүнд чи зөвхөн үнэнтэй нийцэхгүй хэдхэн үйл хийсэн, өөр юу ч хийгээгүй мэт харагдаж болох юм. Гэхдээ Бурханы нүдээр бол чи аль хэдийн ямар ч нүглийн тахилгүй болсон хүн гэдгээ мэдэж байна уу? Чи Бурханы захиргааны зарлигийг нэгээс олон удаа зөрчсөн, түүнчлэн ямар ч гэмшсэн шинж тэмдэг үзүүлээгүй тул Бурхан хүнийг шийтгэдэг там руу унахаас өөр аргагүй. Бурханыг дагах зуураа цөөн тооны хүмүүс зарчмыг зөрчсөн зарим нэг үйл үйлдсэн боловч тэдэнтэй харьцаж, удирдамж өгсний дараа аажмаар завхралаа олж мэдээд, дараа нь бодит байдлын зөв замд орсон бөгөөд өнөөдөр ул суурьтай

хэвээр байдаг. Ийм хүмүүс бол эцэстээ үлдэх хүмүүс юм. Гэвч Би үнэнч шударга хүмүүсийг эрж хайдаг; хэрвээ чи үнэнч шударга, зарчмын дагуу үйлддэг хүн бол Бурханы ойр дотнын хүн байж чадна. Хэрвээ үйлдлүүдээрээ чи Бурханы зан чанарт халддаггүй, Бурханы хүслийг эрж хайдаг, Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэлтэй бол итгэл чинь стандартад нийцнэ. Бурханыг хүндэлдэггүй, зүрх сэтгэл нь айн чичирдэггүй хэн боловч Бурханы захиргааны зарлигийг зөрчих өндөр магадлалтай. Олон хүн урам зоригоороо Бурханд үйлчилдэг боловч Бурханы захиргааны зарлигийн талаар огт ойлгодоггүй, Түүний үгийн утгыг бүр ч таамагладаггүй. Иймээс сайн санаа зорилгоороо тэд үргэлж Бурханы удирдлагад саад болох зүйлс хийж дуусдаг. Ноцтой тохиолдолд, тэд хөөгдөж, Түүнийг дагах өөр ямар ч боломжгүй болдог бөгөөд там руу хаягдаж, Бурханы гэртэй харилцах бүх харилцаа нь төгсдөг. Энэ хүмүүс мунхаг сайн санааныхаа хүчээр Бурханы гэрт ажилладаг бөгөөд эцэстээ Бурханы зан чанарыг уурлуулдаг. Хүмүүс албан тушаалтан, ноёдод үйлчилдэг арга замаа Бурханы гэрт авчирч, хэрэгжүүлэхээр оролдож, тэдгээрийг энд хялбархан хэрэглэж болно гэж хий дэмий бодож байдаг. Бурхан бол хурганы биш, харин арслангийн зан чанартай гэдгийг тэд хэзээ ч төсөөлж байгаагүй. Тиймээс Бурхантай анх удаа холбогдож байгаа хүмүүс Түүнтэй ярилцаж чаддаггүй, учир нь Бурханы зүрх сэтгэл хүнийхтэй адилгүй билээ. Олон үнэнийг ойлгосныхоо дараа л чи Бурханыг тасралтгүй мэдэж авч чадна. Энэ мэдлэг нь үг хэллэг, хоосон сургаалаас бүрддэггүй, харин Бурхантай ойр дотно болох эрдэнэс, Тэр чамд баярладгийн нотолгоо болон хэрэглэгдэж болно. Хэрвээ чи бодит мэдлэгээр дутмаг, үнэнээр зэвсэглээгүй бол урам зоригтой үйлчлэл чинь Бурханы жигшил, зэвүүцлийг л төрүүлж чадна. Одоо чи Бурханд итгэх итгэл гэдэг бол теологи судлах төдий зүйл биш гэдгийг мэдсэн байх ёстой!

Та нарт сануулж буй Миний үг товчхон хэдий ч Миний хэлсэн бүхэн та нарт хамгийн их дутагддаг зүйл юм. Одоо Миний хэлж буй зүйл хүмүүсийн дундах Миний эцсийн ажлын төлөө, мөн хүний төгсгөлийг тодорхойлохын төлөө байдгийг та нар мэдэх ёстой. Би ямар ч зорилгогүй ихээхэн ажил хийхийг хүсдэггүй, өмхөрсөн мод шиг найдваргүй хүмүүсийг үргэлжлүүлэн залж чиглүүлэхийг ч хүсдэггүй, нууцаар муу санаа өвөрлөдөг хүмүүсийг үргэлжлүүлэн удирдахыг бүр ч хүсдэггүй. Магадгүй нэг л өдөр та нар Миний үгийн ард буй чин сэтгэлийг болон хүн төрөлхтөнд оруулсан хувь нэмрийг ойлгоно. Магадгүй нэг л өдөр та нар өөрсдийн чинь төгсгөлийг тодорхойлох үнэнийг ухаарна.

ГЭМ БУРУУ НЬ ХҮНИЙГ ТАМ РУУ ХӨТӨЛНӨ

Би та нарт олон анхааруулга өгч, та нарыг байлдан дагуулахын тулд олон үнэнийг хайрласан. Одоо та нарт өмнөхөөсөө нэлээд их сайжирч, хүн ямар байх ёстой тухай олон зарчмыг ойлгож авч, итгэлтэй хүмүүст байх ёстой эрүүл ухаанаас

маш ихийг эзэмшдэг болсон мэт санагддаг. Энэ бүхэн нь та нарын олон жилийн туршид хүрсэн үр дүн юм. Би та нарын амжилтыг үгүйсгэдэггүй боловч энэ олон жилийн турш Миний эсрэг тоо томшгүй олон удаа дуулгаваргүй байж, тэрсэлснийг чинь ч бас үгүйсгэдэггүй гэдгээ илэн далангүй хэлэх ёстой, учир нь та нарын дунд ганц ч ариун хүн байхгүй. Та нар бүгд ялгаагүй Сатаны завхруулсан хүмүүс юм; та нар бол Христийн дайснууд билээ. Өнөөг хүртэлх та нарын гэм буруу болон дуулгаваргүй байдал тоо томшгүй их байсаар ирсэн тул та нарт үргэлж үглэж яншиж байгааг минь бараг л гайхах зүйлгүй. Би та нартай хамт ийм маягаар амьдармааргүй байгаа ч ирээдүй болон хүрэх газрын чинь төлөө дахиад нэг үглээ. Та нар Надад хүлээцтэй хандахын сацуу айлдвар бүрд минь итгэж, Миний үгийн гүн гүнзгий утга санааг дүгнэж чадна гэж Би найдаж байна. Миний хэлдэг зүйлд эргэлзэж болохгүй, Миний үгийг хүссэнээрээ аваад дурааараа хаяж бүр ч болохгүй; ингэх нь Надад тэвчихийн аргагүй санагддаг. Миний үгийг битгий шүүмжил, бүү хөнгөн хуумгай авч үз, Би та нарыг үргэлж уруу татаж байна гэж битгий ярь, эсвэл та нарт Миний хэлсэн зүйл алдаа мадагтай гэж бүр ч битгий хэл. Эдгээр зүйл ч бас Надад тэвчихийн аргагүй санагддаг. Та нар Надад болон Миний хэлдэг зүйлд ингэж сэжиглэн хандаж, Миний үгийг хэзээ ч ойлголгүй, Намайг үл ойшоодог учраас Би та бүхэнд нухацтайгаар хэлье: Миний хэлдэг зүйлийг гүн ухаантай бүү холбо; Миний үгийг зальт этгээдийн худал үгтэй бүү холбо. Тэр ч бүү хэл, Миний үгэнд басамжлалаар бүү хариул. Магадгүй ирээдүйд хэн ч та нарт Миний хэлж байгаа зүйлийг хэлж өгч чадахгүй, та нартай ийм өр зөөлнөөр ярилцахгүй, тэр ч байтугай эдгээр зүйлийг нэгд нэггүй тэвчээртэйгээр тайлбарлахгүй. Та нар сайхан цагаа дурсах юм уу чангаар эхэр татан уйлж, эсвэл өвчиндөө ёолж айсуй өдөр хоногуудыг өнгөрөөнө, аль эсвэл үнэн юм уу амийн өчүүхэн төдий ч хангалтгүйгээр харанхуй шөнүүдийг туулж, эсвэл зүгээр л ямар ч найдваргүйгээр хүлээх юм уу хамаг ухаанаа алдталаа маш их харамсах болно… Эдгээр боломжоос та нарын хэн нь ч бараг зайлсхийж чадахгүй. Учир нь та нарын нэг нь ч Бурханыг үнэхээр шүтэн мөргөдөг байр сууринд байдаггүй, харин садар самуун, муу ёрын ертөнцөд автаж, амь, үнэнтэй ямар ч хамаагүй, үнэндээ тэдгээрийн эсрэг байдаг маш олон зүйлийг өөрсдийн итгэл, сүнс, сэтгэл, биед хольдог. Тиймээс та нар гэрлийн замд хүрч чадна гэж Би найдаж байна. Та нар өөрсдийгөө халамжилж, өөрсдөдөө санаа тавих чадвартай болно, мөн ааш авир, гэм буруугаа үл хайхрангаа хүрэх газартаа хэт их ач холбогдол өгөхгүй байж чадна гэдэг бол Миний цорын ганц найдвар юм.

Бурханд удаан хугацаанд итгэсэн хүмүүс гайхалтай сайхан хүрэх газартай болно гэж чин сэтгэлээсээ найдсаар ирсэн бөгөөд өөрсдөд нь зол завшаан гэнэт тохионо гэж Бурханы бүх итгэгч найддаг. Тэгээд нэг л мэдэхэд тэнгэрт хаа нэгтээ амар амгалан сууж байх болно гэж тэд бүгд найддаг. Гэхдээ сайхан бодолтой энэ хүмүүс тэнгэрээс унаж ирэх тийм сайн зол завшааныг хүлээн авах юм уу тэнгэр дэх суудалд суухад тэнцэх эсэхээ ч огт мэдээгүй гэж Би хэлдэг. Та нар одоо өөрсдийгөө сайн мэддэг хэр нь эцсийн өдрүүдийн гай гамшиг болон муу хүмүүсийг шийтгэдэг

Төгс Хүчитийн гараас зугтаж чадна гэж найдсаар байгаа. Сайхан мөрөөдөлтэй байж, аливааг өөрсдийнхөөрөө байлгахыг хүсэх нь ганц нэг хүний гайхалтай санаа биш, харин Сатаны завхруулсан бүх хүний нийтлэг онцлог юм шиг санагддаг. Тэгсэн ч гэсэн Би та нарын хэрээс хэтэрсэн энэ хүсэл болон ерөөл хүртэх гэсэн эрмэлзлийг эцэс болгохыг хүссээр л байна. Та нарын гэм буруу тоо томшгүй, тэрслүү байсан баримтууд ч үргэлж нэмэгдэж байхад ирээдүйн төлөөх сайхан төлөвлөгөө чинь үүнтэй яаж тохирох юм бэ? Чи биеэ огт барилгүйгээр, хүссэнээрээ алдаа гаргадаг атлаа мөрөөдөл чинь биелээсэй гэж хүссээр байгаа бол гүн нойрссоор байж, хэзээ ч бүү сэр гэж Би чамайг шавдуулна—учир нь чинийх бол хий хоосон мөрөөдөл бөгөөд зөвт Бурханы өмнө Тэр чамайг онцлон үзэхгүй. Хэрвээ чи мөрөөдөл чинь биелээсэй гэж л хүсдэг бол хэзээ ч бүү мөрөөд; харин үнэн болон баримттай үүрд нүүр тул. Энэ л чиний аврагдаж болох цорын ганц зам юм. Энэхүү арга барилын тодорхой алхмууд юу вэ?

Нэгдүгээрт, бүх гэм буруугаа харж, үнэнтэй нийцдэггүй бүх ааш авир, бодлоо шинжил.

Та нарын амархан хийж чадах нэг зүйл бол энэ бөгөөд оюун ухаантай бүх хүн үүнийг хийж чадна гэж Би итгэж байна. Гэвч, гэм буруу болон үнэн гэж юу гэсэн үг болохыг огт мэддэггүй хүмүүс үүнд хамаарахгүй, учир нь үндсэндээ тэд бол оюун ухаантай хүмүүс биш юм. Би Бурханаар хүлээн зөвшөөрөгдсөн, үнэнч, захиргааны ямар ч зарлигийг ноцтой зөрчөөгүй, гэм буруугаа амархан таньж мэддэг хүмүүстэй ярилцаж байна. Та нараас Миний шаарддаг энэ нэг зүйлийг биелүүлэхэд амархан хэдий ч энэ нь та нараас Миний шаарддаг цорын ганц зүйл биш. Ямартай ч, энэ шаардлагыг та нар нууцаар шоолохгүй, ялангуяа үүнийг дорд үзэж, хөнгөн хуумгай хандахгүй гэж Би найдаж байна. Үүнд нухацтай хандах ёстой ба хайхрамжгүй хандаж болохгүй.

Хоёрдугаарт, гэм буруу болон дуулгаваргүй байдал бүрдээ холбогдох үнэнийг эрж хайн, энэ үнэнийг ашиглан тэдгээр асуудлыг шийдвэрлэ. Тэгээд дараа нь гэм буруутай үйл хэрэг болон дуулгаваргүй бодол, үйлдлээ үнэний хэрэгжүүлэлтээр орлуул.

Гуравдугаарт, үргэлж сүйхээтэй, байнга овжин байдаг биш, харин үнэнч хүн бай. (Энд Би та нараас үнэнч хүн байгаач гэж дахин хүсэж байна.)

Энэ гурван зүйлийг бүгдийг нь биелүүлж чаддаг бол чи хувьтай хүмүүсийн нэг буюу мөрөөдөл нь биелж, сайн зол завшаан хүртдэг хүн юм. Та нар энэ гурван таагүй хүсэлтэд нухацтай хандаж магадгүй, эсвэл хариуцлагагүй хандаж магадгүй. Аль нь ч бай, Миний зорилго бол та нарын мөрөөдлийг биелүүлж, туйлын зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө болохоос та нараар даажигнаж, тоглоом хийх явдал биш юм.

Миний шаардлагууд энгийн байж болох ч та нарт хэлж байгаа зүйл минь нэг дээр нэгийг нэмээд хоёр гэдэг шиг тийм ч энгийн биш. Хэрвээ та нар энэ тухай хамаагүй ярьж, хий дэмий ихэрхүү үг чалчихаас өөрийг хийдэггүй бол хүсэл, төлөвлөгөө чинь үүрд хий хоосон байх болно. Олон жилийн турш зовж, шаргуу

ажилласан мөртөө харуулах юм юу ч үгүй та нарыг Би огт өрөвдөхгүй. Эсрэгээрээ, Миний шаардлагад нийцээгүй хүмүүсийг Би өрөвдөх нь байтугай шагнал биш, шийтгэлээ хүртээнэ. Та нар олон жилийн турш дагалдагч байснаараа ямартай ч шаргуу ажилласан бөгөөд зүгээр л үйлчлэл үзүүлэгч байсныхаа төлөө Бурханы гэрээс аяга будаа хүртэж ёстой гэж төсөөлж байж магадгүй. Та нар ямар нэг зүйлийг ашиглаад, хариуд нь өөрсдийгөө ашиглуулахгүй байх зарчмыг үргэлж эрэлхийлж ирсэн учраас дийлэнх чинь ингэж боддог гэж Би хэлнэ. Тиймээс Би одоо та нарт тун нухацтайгаар хэлж байна: Шаргуу ажил чинь хэр гавьяатайг, чадвар чансаа чинь хэр сүрхийг, Намайг хэр ойр дагадаг, хэр их нэр цуутайг чинь, эсвэл хандлагаа хэр их сайжруулсныг чинь Би хайхардаггүй; Миний шаардлагад нийцээгүй л бол чи Миний магтаалыг хэзээ ч хүртэж чадахгүй. Энэ бүх санаа, тооцооллоо аль болох эртхэн орхиод Миний шаардлагад нухацтай хандаж эхэл; эс бөгөөс, Би ажлаа дуусгахын тулд бүх хүнийг үнс нурам болгож, хамгийн муудаа л олон жилийн ажил, зовлон шаналлаа талаар болгоно, учир нь Би Өөрийн дайснууд болон ёрын муу ханхлуулсан, Сатаны төрхтэй хүмүүсийг хаанчлалдаа юм уу дараагийн эрин үед аваачиж чадахгүй.

Надад маш их найдлага бий. Та нар биеэ зүй зохистой, хүмүүжилтэй байдлаар авч явж, үүргээ үнэнчээр биелүүлж, үнэн болон хүн чанарыг эзэмшиж, байгаа бүхнээ, бүр амиа ч гэсэн Бурханы төлөө өгч чадна гэх зэргээр Би найддаг. Энэ бүх итгэл найдвар та нарын дутагдал, завхрал, дуулгаваргүй байдлаас үүддэг. Та нартай ярилцсан ярианаас минь нэг нь ч анхаарлыг чинь татахуйц байгаагүй бол Би дахиад юм хэлэхгүй байсан нь дээр бололтой. Гэхдээ та нар үүний үр дүн ямар байхыг ойлгож байгаа. Би бараг амардаггүй тул хэрвээ Би үг хэлэхгүй бол хүмүүсийн харж болох ямар нэг зүйлийг хийнэ. Би хэн нэгний хэлийг өмхийрүүлж, хэн нэгнийг мөчлөн үхүүлж, эсвэл хүмүүсийг сэтгэцийн эмгэгтэй болгож, маш олон арга замаар үзэшгүй муухай харагдуулж чадна. Бас Би өөрсдөд нь зориулж тусгайлан нэрсэн тарчлаанаа хүмүүст амсуулж чадна. Ингэвэл Би баяр хөөртэй, маш аз жаргалтай, тун сэтгэл ханамжтай байна. “Сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хорлол” гэж дандаа хэлдэг байсан, тэгвэл одоо яагаад болохгүй гэж? Хэрвээ чи Намайг эсэргүүцэж, Надад шүүмжлэлтэй хандмаар байвал Би амыг чинь өмхийрүүлж, үүндээ эцэс төгсгөлгүйгээр баясна. Учир нь эцсийн эцэст, чиний хийсэн зүйл бол үнэн биш, тэр ч байтугай амьтай ямар ч хамаагүй байхад Миний хийдэг бүхэн бол үнэн юм; Миний бүх үйлдэл ажлын минь зарчим болон Миний тогтоосон захиргааны зарлигтай хамаатай байдаг. Тиймээс дор бүрнээ жаахан сайн чанар хуримтлуулж, ийм их мууг хийдгээ больж, завтай цагтаа Миний шаардлагуудыг анхаар гэж Би та нарыг шавдуулж байна. Тэгвэл Би баярлана. Хэрвээ та нар махан биедээ зориулдаг хичээл зүтгэлийнхээ мянганы нэгийг үнэнд нэмэрлэдэг (эсвэл хандивладаг) байсан бол байнга гэм буруу үйлдэж, өмхийрсөн амтай явахгүй байх байсан гэдгийг Би хэлэх байна. Энэ нь илэрхий биш гэж үү?

Чи хэдий чинээ их гэм буруу үйлдэнэ, сайн хүрэх газар олж авах боломж чинь төдий чинээ бага байдаг. Харин эсрэгээрээ, гэм буруу бага үйлдэх тусам, Бурханаар магтуулах боломж чинь улам их байна. Надаар уучлуулах боломжгүй болтлоо гэм буруу чинь ихэсвэл уучлагдах боломжоо чи бүрмөсөн алдсан байх болно. Тэгвэл, хүрэх газар чинь дээр биш, харин доор байна. Хэрвээ Надад итгэхгүй байгаа бол чи зориг гаргаад, бурууг үйлд, тэгээд юунд хүрэхээ хар. Хэрвээ чи үнэнийг чин сэтгэлээсээ хэрэгжүүлдэг хүн бол гэм буруугаа уучлуулах боломжтой байх нь гарцаагүй бөгөөд дуулгаваргүй байх чинь улам багасаж, улам цөөрнө. Хэрвээ чи үнэнийг хэрэгжүүлэхийг хүсдэггүй хүн бол Бурханы өмнөх гэм буруу чинь гарцаагүй ихсэж, дуулгаваргүй байдлын чинь хэмжээ хязгаартаа хүртлээ улам бүр нэмэгдэх бөгөөд тэр нь бүрмөсөн устах цаг чинь байх болно. Тэр үед ерөөл хүртэх гэсэн таатай мөрөөдөл чинь сүйрнэ. Өөрийн гэм бурууг томоогүй, тэнэг хүний алдаа төдий гэж бүү үз, мөн дорд хэв чанар чинь боломж олгоогүй болохоор үнэнийг хэрэгжүүлээгүй гэх шалтаг бүү тооч. Түүнчлэн үйлдсэн гэм буруугаа гагцхүү юм мэдэхгүй хүний үйлдэл гэж бүү үз. Хэрвээ чи өөрийгөө уучилж, өр зөөлөн хандахдаа сайн бол үнэнийг хэзээ ч олж авахгүй хулчгар бөгөөд гэм буруу чинь чамайг зовоохоо хэзээ ч болихгүй, харин чамайг үнэний шаардлагад хэзээ ч нийцүүлэлгүй, үүрд Сатаны үнэнч хамтрагч хэвээр үлдээнэ гэдгийг Би хэлье. Чамд өгөх Миний зөвлөгөө мөн л энэ: Өөрийнхөө хүрэх газарт анхааралд нуугдмал гэм буруугаа анзааралгүй бүү үлдээ; гэм бурууг ноцтойгоор авч үз, хүрэх газартаа санаа зовсноосоо болоод ямар нэг гэм буруугаа бүү орхигдуул.

БУРХАНЫ ЗАН ЧАНАРЫГ ОЙЛГОХ НЬ МАШ ЧУХАЛ

Би та нарыг олон зүйлд хүрнэ гэж найддаг ч та нарын бүх үйлдэл, амьдралын чинь бүх байдал Миний шаардсан зүйлийг бүрэн биелүүлж чаддаггүй, иймээс шууд гол зүйлдээ орж, Өөрийнхөө хүслийг та нарт тайлбарлахаас өөр сонголт Надад алга. Та нарын ялган таних чадвар дульхан, сонирхох чадвар ч мөн адил тааруухан болохоор Миний зан чанар, мөн чанарын талаар бараг юу ч мэддэггүй, тиймээс тэр талаар та нарт мэдэгдэх нь яаралтай асуудал болоод байна. Өмнө нь хэр ихийг ойлгосон чинь хамаагүй, эдгээр асуудлыг ойлгохыг хүсдэг эсэхээс чинь үл хамааран Би эдгээрийг бас л дэлгэрэнгүй тайлбарлах ёстой. Эдгээр асуудал та нарын огт мэддэггүй зүйл биш боловч эдгээрт агуулагддаг утга учрын талаар та нарт ихээхэн ойлголт, мэдлэг дутагддаг. Та нарын олонх нь ердөө л бүдэг бадаг ойлголттой байдаг ба тэр нь хагас дутуу, бүрэн бус байдаг. Үнэнийг илүү сайн хэрэгжүүлж, Миний үгийг илүү сайн хэрэгжүүлэхэд нэмэр болгохын тулд та нар эдгээр асуудлыг эн түрүүнд мэдэх ёстой гэж Би бодож байна. Тэгэхгүй бол та нарын итгэл тодорхойгүй, хуурамч агаад шашны шинж тэмдгээр дүүрэн хэвээр үлдэнэ. Хэрвээ чи Бурханы зан чанарыг ойлгодоггүй бол Түүний төлөө хийх учиртай ажлаа

хийх боломжгүй болно. Хэрвээ чи Бурханы мөн чанарыг мэддэггүй бол Түүнийг хүндэлж, Түүнээс айх боломжгүй болно; харин жишимгүй хааш яаш байдал, булзаарал, түүнчлэн засаж боломгүй доромжлол л байх болно. Бурханы зан чанарыг ойлгох нь үнэхээр чухал бөгөөд Бурханы мөн чанарыг мэдэх явдлыг орхигдуулж болохгүй хэдий ч эдгээр асуудлыг хэн ч нягтлан шалгаж, эсвэл нарийвчлан судлаагүй. Та нар бүгдээрээ Миний гаргасан захиргааны зарлигийг үл тоомсорлосон нь харахад илт байдаг. Хэрвээ та нар Бурханы зан чанарыг ойлгодоггүй бол Түүний зан чанарт халдаж тун болзошгүй. Түүний зан чанарт халдах нь Бурханы Өөрийн уур хилэнг хүргэхтэй адилхан бөгөөд тэр тохиолдолд үйлдлийн чинь эцсийн үр дүн нь захиргааны зарлигийг зөрчсөн хэрэг болно. Бурханы мөн чанарыг мэдэх үедээ зан чанарыг нь ч ойлгож чадах бөгөөд Бурханы зан чанарыг ойлгох үедээ захиргааны зарлигийг ч бас ойлгосон байна гэдгээ чи одоо ухаарах хэрэгтэй. Мэдээж, захиргааны зарлигт агуулагддаг зүйлийн ихээхэн нь Бурханы зан чанарыг хөнддөг боловч захиргааны зарлигт Түүний зан чанар бүхэлдээ илэрхийлэгддэггүй; иймд та нар Бурханы зан чанарын талаарх ойлголтоо дахиад нэг алхам гүнзгийрүүлэх ёстой.

Би өнөөдөр та нартай энгийн нэг яриа яриагүй, иймээс та нар Миний үгэнд анхааралтай хандахаас гадна тэдгээрийг гүнээ эргэцүүлбэл зохино. Үүгээр Би юу гэж байна вэ гэвэл, та нар Миний хэлсэн үгэнд хэтэрхий бага хичээл чармайлт гаргасан. Мөн Бурханы зан чанарыг тунгаан бодохыг бүр ч хүсдэггүй; тийм чармайлт гаргадаг хүн ховорхон. Ийм учраас, та нарын итгэл бол гоёмсог, сүржин ярианаас цаашгүй гэж Би хэлдэг. Одоо ч гэсэн та нарын нэг нь ч эмзэг талаа засах гэж нухацтай хичээсэн нь огт үгүй. Та нарын төлөө амссан бүх зовлон шаналлын минь дараа та нар Миний урмыг хугалсан. Та нар Бурханыг огт тоодоггүй агаад амьдрал чинь үнэнгүй байдагт гайхах зүйлгүй. Ийм хүмүүсийг яаж ариун хүмүүс гэж үзэж болох юм бэ? Тэнгэрийн хууль тийм зүйлийг тэвчихгүй! Та нар энэ талаар маш бага ойлголттой байгаа тул илүү их цаг зарцуулахаас өөр сонголт Надад алга.

Бурханы зан чанар бол хүн бүхэнд маш хийсвэр санагддаг сэдэв бөгөөд түүнчлэн Түүний зан чанар хувь хүний зан ааштай адилгүй учир хэний ч хувьд хүлээн зөвшөөрөхөд амаргүй сэдэв билээ. Бурханд ч бас Өөрийн гэсэн баяр хөөр, уур хилэн, уй гашуу, аз жаргалын сэтгэл хөдлөл байдаг боловч эдгээр сэтгэл хөдлөл хүнийхээс ялгаатай. Бурханд Өөрийн гэсэн оршихуй болон эзэмшил байдаг. Түүний илэрхийлж, харуулдаг бүхэн бол Түүний мөн чанар, ялгамж чанарын төлөөлөл юм. Тэр юу болох, Түүнд юу байгаа, мөн Түүний мөн чанар, ялгамж чанар нь ямар ч хүн орлож чадахгүй зүйл юм. Түүний зан чанар нь хүн төрөлхтнийг гэх Түүний хайр, хүн төрөлхтнийг тайтгаруулах тайтгарал, хүн төрөлхтөнд хандах үзэн ядалт, мөн түүнээс гадна хүн төрөлхтний талаарх нэвт шувт ойлголтыг агуулдаг. Хүний зан ааш харин өөдрөг, золбоолог юм уу мэдрэлгүй байж болох юм. Бурханы зан чанар нь бүх зүйл болон амьд амьтдын Захирагч, Бүтээгчийн эзэмшдэг зүйл билээ. Түүний зан чанар нь нэр төр, хүч чадал, эрхэм дээд, агуу байдал болон хамгийн гол нь, дээдийн дээд

байдлыг төлөөлдөг. Түүний зан чанар бол эрх мэдлийн бэлгэ тэмдэг, зөвт бүхний бэлгэ тэмдэг, сайн сайхан бүхний бэлгэ тэмдэг билээ. Түүнээс гадна, энэ нь харанхуй болон дайсны ямар ч хүчинд үл дийлдэх буюу довтлогдошгүй Түүний бэлгэ тэмдэг төдийгүй ямар ч бүтээгдсэн зүйлийн халдаж үл чадах (Өөрт нь халдахыг Тэр тэвчдэггүй) Түүний бэлгэ тэмдэг юм. Түүний зан чанар бол хамгийн дээд эрх мэдлийн бэлгэ тэмдэг билээ. Хэн ч, ямар ч хүмүүс Түүний ажлыг, Түүний зан чанарыг үймүүлж чадахгүй, болох ч үгүй. Харин хүний зан ааш бол амьтнаас жаахан давуу гэдгийнх нь бэлгэ тэмдэг төдий юм. Хүн өөрөө дангаараа эрх мэдэлгүй, бие даасан байдалгүй, өөрийгөө дийлэх чадваргүй, харин мөн чанартаа төрөл бүрийн хүмүүс, үйл явдал, юмсын эрхшээлд навталздаг нэгэн юм. Бурханы баяр хөөр нь зөвт байдал болон гэрлийн оршин тогтнол, үүслээс бий болдог, мөн харанхуй болон ёрын муу устсанаас бий болдог. Хүн төрөлхтөнд гэрэл болон сайхан амьдрал авчрахдаа Тэр баярладаг; Түүний баяр хөөр бол зөвт баяр хөөр, эерэг бүхний оршин тогтнолын бэлгэ тэмдэг, түүнээс гадна таатай байдлын бэлгэ тэмдэг юм. Бурханы уур хилэн нь, шударга бус явдлын оршин тогтнол, хөндлөнгийн оролцооны хүн төрөлхтөнд нь учруулдаг хор хөнөөлөөс болж, мөн ёрын муу болон харанхуйн оршин тогтнолоос, үнэнийг хөөн зайлуулдаг зүйлсийн оршин тогтнолоос, цаашлаад сайн сайхан бүхнийг эсэргүүцдэг зүйлсийн оршин тогтнолоос болж төрдөг. Түүний уур хилэн бол бүх сөрөг зүйл оршин тогтнохоо болихын бэлгэ тэмдэг байдгаас гадна, Түүний ариун байдлын бэлгэ тэмдэг юм. Түүний уй гашуу нь, Өөрийнх нь итгэж найддаг боловч харанхуйд унасан хүн төрөлхтнөөс, хүн дээр хийдэг ажлынх нь үр дүн санаанд нь хүрдэггүйгээс, Өөрийнх нь хайрладаг хүн төрөлхтөн бүгд гэрэлд амьдарч чаддаггүйгээс болдог. Тэрээр гэмгүй хүн төрөлхтний төлөө, үнэнч боловч мэдлэггүй хүний төлөө, сайн боловч өөрийн гэсэн үзэл бодол дутмаг хүний төлөө гунигладаг. Түүний уй гашуу бол Түүний сайн сайхан болон өршөөлийн бэлгэ тэмдэг, гоо үзэсгэлэн, сайхан сэтгэлийн бэлгэ тэмдэг юм. Түүний аз жаргал мэдээж, Өөрийн дайснуудыг ялж, хүний чин сэтгэлийг олж авахаас үүсдэг. Үүнээс ч илүүтэйгээр, энэ нь дайсны бүх хүчийг хөөн зайлуулж, устгахаас бий болдог, мөн хүн төрөлхтөн сайн сайхан, амар амгалан амьдралыг хүлээн авдаг учраас бий болдог. Бурханы аз жаргал хүний баяр хөөртэй адилгүй; харин энэ нь сайн үр жимс хураах мэдрэмж, баяр хөөрөөс ч илүү агуу мэдрэмж юм. Түүний аз жаргал бол энэ мөчөөс эхлээд хүн төрөлхтөн зовлонгоос чөлөөлөгдөхийн бэлгэ тэмдэг, мөн хүн төрөлхтөн гэрлийн ертөнцөд орохын бэлгэ тэмдэг билээ. Нөгөө талаар, хүн төрөлхтний сэтгэл хөдлөл нь бүгд өөрийнх нь хувийн ашиг сонирхлын төлөө гарч ирдгээс биш зөвт байдал, гэрэл, эсвэл сайхан зүйлийн төлөө байдаггүй, Тэнгэрээс хайрласан нигүүлслийн төлөө бүр ч байдаггүй. Хүн төрөлхтний сэтгэл хөдлөл нь аминчхан агаад харанхуйн ертөнцөд харьяалагддаг. Тэдгээр нь Бурханы хүслийн төлөө оршдоггүй, Бурханы төлөвлөгөөний төлөө бүр ч оршдоггүй, иймээс хүн, Бурхан хоёрыг хэзээ ч зэрэгцүүлэн харьцуулж болохгүй. Бурхан үүрд дээдийн дээд, хэзээд эрхэмсэг байхад хүн үүрд олиггүй, үүрд үнэ цэнгүй байдаг. Яагаад

гэвэл, Бурхан үүрд хүн төрөлхтний төлөө золиос гаргаж, зориулж байдаг; гэтэл хүн үүрд өөртөө л авч, өөрийнхөө төлөө зүтгэдэг. Бурхан хүн төрөлхтнийг оршин байлгахын төлөө хүч чадлаа үүрд дайчилдаг байхад хүн гэрлийн төлөө юм уу зөв шударга байдлын төлөө хэзээ ч, ямар ч хувь нэмэр оруулдаггүй. Хүн хэсэг хугацаанд хичээл чармайлт гаргадаг ч гэсэн, тэр нь ганц цохилт ч дааж чаддаггүй, учир нь хүний хичээл чармайлт бусдын төлөө биш, үргэлж өөрийнх нь төлөө байдаг. Хүн үргэлж хувиа хичээдэг байхад Бурхан үүрд сэтгэл харамгүй байдаг. Бурхан бол шударга, сайн, сайхан бүхний эх сурвалж байхад хүн бол муухай, ёрын муу бүхнийг өвлөн авч, ил харуулдаг нэгэн юм. Бурхан шударга байдал болон гоо сайхны мөн чанараа хэзээ ч өөрчлөхгүй, харин хүн хэдийд ч, ямар ч нөхцөлд зөв шударга байдлаас урваж, Бурханаас холдон одохоос ер сийхгүй.

Миний хэлсэн өгүүлбэр болгон Бурханы зан чанарыг агуулдаг. Та нар Миний үгийг анхааралтай эргэцүүлсэн нь дээр, тэгвэл асар их ашиг тус хүртэх нь гарцаагүй. Бурханы мөн чанарыг ухаарахад маш хэцүү боловч та нар бүгдээрээ Бурханы зан чанарын тухай жаахан ч атугай мэднэ гэж Би итгэж байна. Тэгээд та нар Бурханы зан чанарт халдахгүй зүйл илүү ихийг хийснээ Надад харуулна гэж найдаж байна. Тэгвэл Миний санаа амарна. Жишээлбэл, Бурханыг цаг үргэлж зүрх сэтгэлдээ байлга. Аливааг үйлдэхдээ Түүний үгийн дагуу хий. Бүх зүйлээс Түүний санаа зорилгыг эрж хай, мөн Бурханыг үл хүндэлж, гутаах зүйл хийхийг цээрлэ. Чи өөрийнхөө зүрх сэтгэлийн хожмын хоосролоо дүүргэхийн тулд Бурханыг сэтгэлийнхээ мухарт хийж бүр ч болохгүй. Хэрвээ тэгэх юм бол Бурханы зан чанарт халдсан байх болно. Дахин хэлэхэд, чи насан туршдаа хэзээ ч Бурханыг хараан доромжилж, Түүнд гомдоллоогүй гэж үзье, мөн Түүний даалгасан бүхнийг зохих ёсоор биелүүлж, насан туршдаа Түүний бүх үгэнд захирагдаж чаддаг гэж үзье, тэгвэл чи захиргааны зарлигийг зөрчихөөс зайлсхийсэн байна. Жишээлбэл, хэрвээ чи хэзээ нэгэн цагт “Би яагаад Түүнийг Бурхан гэж боддоггүй юм бэ?”, “Эдгээр үг Ариун Сүнсний гэгээрлээс цаашгүй байх”, “Миний бодлоор бол, Бурханы хийдэг бүхэн зөв байх албагүй”, “Бурханы хүн чанар минийхээс давуу биш”, “Бурханы үг зүгээр л үнэмшилгүй” гэдэг ч юм уу, эсвэл өөр иймэрхүү шүүмжилсэн үг хэлж байсан бол нүглээ илүү олонтоо улайж, гэмш гэж Би чамд сануулж байна. Эс бөгөөс уучлуулах боломж чамд хэзээ ч гарахгүй, учир нь чи хүнд биш, харин Бурханд Өөрт нь халддаг. Чи хүнийг шүүмжилж байна гэж бодож болох ч Бурханы Сүнс тэгж үздэггүй. Түүний махбодыг үл хүндлэх нь Түүнийг үл хүндлэхтэй адилхан. Тэгэхээр хийсэн бүхэн чинь Бурханы зан чанарт халдсан бус уу? Бурханы Сүнсний хийдэг бүхэн нь махбодод хийсэн Түүний ажлыг хамгаалахын төлөө, энэхүү ажлыг сайн хийхийн төлөө байдаг гэдгийг чи санах ёстой. Хэрвээ үүнийг үл ойшоовол чи Бурханд итгэхдээ хэзээ ч амжилт гаргаж чадахгүй хүн юм гэж Би хэлнэ. Чи Бурханы уур хилэнг хүргэсэн учраас чамд сургамж өгөхийн тулд Тэр тохирох шийтгэлийг ашиглана.

Бурханы мөн чанарыг мэдэж авах нь ялихгүй асуудал биш. Чи Түүний зан чанарыг ойлгох ёстой. Ийм маягаар аажмаар, өөрийн мэдэлгүйгээр Бурханы мөн

чанарыг мэдэж авна. Энэ мэдлэгт орохоороо чи илүү өндөр, илүү сайхан ертөнц рүү алхаж байгаагаа олж мэднэ. Эцэст нь чи үзэшгүй муухай сүнснээсээ ичихээс гадна ичгүүрээсээ нуугдах газар хаа ч үгүй гэж санагдана. Тэр үед Бурханы зан чанарт халдах үйлдэл чинь улам бүр багасаж, зүрх сэтгэл чинь Бурханыхтай улам бүр ойртож, Түүнийг гэх хайр зүрх сэтгэлд чинь аажмаар өсөн нэмэгдэнэ. Энэ бол хүн төрөлхтөн гайхалтай сайхан ертөнцөд орж буйн тэмдэг юм. Гэхдээ та нар үүнд хараахан хүрээгүй. Та нар бүгд хувь заяаныхаа төлөө яарч тэвддэг тул Бурханы мөн чанарыг мэдэх гэж оролдох сонирхол хэнд байх юм бэ? Ийнхүү үргэлжлэх юм бол та нар өөрийн мэдэлгүй захиргааны зарлигийг зөрчинө, учир нь та нар Бурханы зан чанарын талаар дэндүү бага ойлгодог. Иймээс та нарын одоо хийдэг зүйл Бурханы зан чанарын эсрэг зөрчлийн чинь суурийг тавьж байгаа бус уу? Бурханы зан чанар Миний ажлаас салшгүй гэдгийг ойлгохыг Би та нараас шаардаж байна. Учир нь, захиргааны зарлигийг байнга зөрчдөг бол та нарын дундаас хэн чинь шийтгэлээс зугтах юм бэ? Тэгвэл Миний ажил бүхэлдээ талаар өнгөрөх байсан бус уу? Тиймээс биеэ авч явах байдлаа нягтлан шалгахын зэрэгцээ өөрсдийн хийдэг алхамд хянуур бай гэж Би бас л шаардаж байна. Энэ нь та нарт Миний тавьдаг илүү өндөр шаардлага бөгөөд та нар бүгдээрээ үүнийг нарийвчлан авч үзэж, ул суурьтай анхаарна гэж Би найдаж байна. Та нарын үйлдэл Миний уур хилэнг асар ихээр бадраах өдөр ирэх юм бол та нар өөрсдөө л үр дагаврыг нь амсах ба өөр хэн ч та нарын оронд шийтгэл хүлээхгүй.

ГАЗАР ДЭЭРХ БУРХАНЫГ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ

Бурханы өмнө шагнал хүлээн авч, Бурханаар ивээгдэхийг та нар бүгд хүсдэг; Бурханд итгэж эхлэх үедээ хүн бүр ийм зүйлийг хүсдэг, учир нь хүн бүр илүү өндөр дээд зүйлсийг эрэлхийлэх бодолд автдаг бөгөөд хэн ч бусдаас хоцрохыг хүсдэггүй. Хүмүүс ийм л байдаг. Яг энэ шалтгааны улмаас, та нарын дундаас олон хүн тэнгэр дэх Бурханд тал засахаар байнга хичээдэг ч үнэндээ Бурханыг гэх үнэнч зан, чин сэтгэл чинь өөрсдийгөө гэсэн үнэнч зан, чин сэтгэлээс чинь хавьгүй бага байдаг. Би яагаад ингэж хэлдэг вэ? Учир нь Би Бурханд үнэнч байдлыг чинь огт хүлээн зөвшөөрдөггүй, түүнчлэн та нарын зүрх сэтгэлд оршдог Бурханы оршин тогтнолыг Би үгүйсгэдэг. Өөрөөр хэлбэл, та нарын шүтэн мөргөдөг Бурхан, та нарын гайхан биширдэг тодорхойгүй Бурхан огтхон ч оршин тогтнодоггүй. Би үүнийг маш баттай хэлж буйн шалтгаан нь та нар жинхэнэ Бурханаас хэтэрхий хол байдаг. Та нарын үнэнч зангийн шалтгаан нь зүрх сэтгэл дотор чинь байгаа шүтээн юм; харин та нарын агуу гэж үздэггүй, өчүүхэн ч гэж үздэггүй Бурхан Намайг та нар үгээрээ л хүлээн зөвшөөрдөг. Та нар Бурханаас хэтэрхий хол байдаг гэж Би хэлэхдээ, жинхэнэ Бурханаас хол байдаг ч тодорхойгүй Бурхан тун ойрхон байгаа мэт санагддагийг чинь хэлж байна. Би “агуу биш” гэж хэлсэн нь өнөөдөр та нарын

итгэдэг Бурхан агуу чадваргүй зүгээр л нэг хүн, тийм ч сүрлэг биш хүн шиг харагддагийг хэлж байгаа юм. Мөн “өчүүхэн ч биш” гэж хэлсэн минь, хэдийгээр энэ хүн салхинд тушааж, бороог захирч чадахгүй ч гэсэн, тэнгэр газрыг доргиох ажлыг хийхийн тулд Бурханы Сүнсийг дуудаж, хүмүүсийг бүрмөсөн гайхшруулж чадна гэсэн утгатай. Гаднаа та нар бүгд газар дээрх энэ Христэд маш дуулгавартай мэт харагддаг ч мөн чанартаа Түүнд итгэдэггүй, Түүнийг хайрладаг ч үгүй. Өөрөөр хэлбэл, та нарын үнэхээр итгэдэг нэгэн чинь та нарын мэдрэмжид байдаг тэр тодорхойгүй Бурхан бөгөөд үнэхээр хайрладаг нэгэн чинь та нарын хэзээ ч биечлэн хараагүй мөртөө өдөр, шөнөгүй хүсэн тэмүүлдэг Бурхан юм. Энэ Христэд хандах та нарын итгэл өчүүхэн төдий бөгөөд та нарын хайр юу ч биш. Итгэл гэдэг бол үнэмшил ба итгэлцэл; хайр гэдэг бол хүний зүрх сэтгэл дэх хэзээ ч салшгүй дурлал, бахдал юм. Гэсэн ч өнөөдрийн Христийг гэх та нарын итгэл, хайр үүнээс хавьгүй дор байдаг. Итгэлийн тухайд гэвэл, та нар Түүнд хэрхэн итгэдэг вэ? Хайрын тухайд бол, та нар Түүнийг яаж хайрладаг вэ? Та нар Түүний мөн чанарыг мэдэх нь байтугай, зан чанарыг нь ч ойлгодоггүй, тэгвэл яаж Түүнд итгэлтэй байх юм бэ? Түүнд итгэх итгэлийн чинь бодит байдал хаана байна вэ? Та нар Түүнийг хэрхэн хайрладаг вэ? Түүнийг гэх хайрын чинь бодит байдал хаана байна вэ?

Олон хүн өнөөдрийг хүртэл эргэлзэлгүйгээр Намайг дагасан. Иймээс өнгөрсөн хэдэн жилд та нар ч бас ихээхэн зүдэрсэн. Би та нарын бүгдийнх нь төрөлх зан авир, зуршлуудыг тов тодорхой ухаарсан; та нартай нэг бүрчлэн харилцахад туйлын хүнд бэрх байсаар ирсэн. Харамсалтай нь хэдийгээр Би та нарын талаар ихийг ухаарсан ч та нар Миний талаар юу ч ойлгодоггүй. Та нар төөрөлдөх агшиндаа хүнд мэхлүүлдэг гэж хүмүүсийн хэлдэгт гайхах зүйл алга. Үнэндээ, та нар Миний зан чанарын талаар юу ч ойлгодоггүй, Миний оюун санаанд юу байгааг ухан мэдэж бүр ч чаддаггүй. Өнөөдөр Миний талаарх буруу ойлголт чинь улам нэмэгдэж байгаа бөгөөд Надад итгэх итгэл чинь будилсан итгэл хэвээр үлддэг. Та нар Надад итгэдэг гэж хэлэхийн оронд та нар бүгдээрээ Надад тал засаж, Надад бялдуучлахаар оролдож байна гэж хэлбэл илүү тохирно. Та нарын сэдэл маш энгийн: Бурхан ч бай, эсвэл ямар нэг тодорхой Бурхан ч бай хамаагүй, намайг шагнаж чадах хэнийг ч би дагана, агуу гамшгаас намайг зугтаалгаж чадах хэнд ч би итгэнэ. Аль нь ч надад хамаагүй. Та нарын дунд ийм хүн олон байгаа ба энэ байдал маш ноцтой. Хэрвээ нэгэн өдөр, Христийн мөн чанарыг тодорхой мэддэгээсээ болоод та нараас хэд нь Түүнд итгэдгийг харах туршилт явуулбал, та нарын нэг нь ч Миний хүссэн шиг байж чадахгүй гэдгээс Би айж байна. Иймээс та нар бүгдээрээ энэ асуултыг эргэцүүлж үзсэн нь дээр: Та нарын итгэдэг Бурхан Надаас асар өөр, тийм болохоор Бурханд итгэх итгэлийн чинь мөн чанар тэгвэл юу вэ? Та нар Бурхан гээч зүйлдээ хэдий чинээ итгэнэ, Надаас төдий чинээ холдон явна. Тэгвэл энэ асуудлын мөн чанар юу вэ? Та нараас нэг нь ч энэ асуудлыг эргэцүүлж үзээгүй нь тодорхой, гэхдээ та нар үүний ноцтой байдлыг бодож үзсэн үү? Ийм маягаар үргэлжлүүлэн итгэхийн үр дагаврыг бодож үзсэн үү?

Өнөөдөр та нар олон асуудалтай тулгардаг бөгөөд та нараас нэг нь ч асуудал шийдвэрлэхдээ чадамгай биш. Ийм нөхцөл байдал үргэлжилбэл хохирол амсах хүмүүс нь зөвхөн та нар юм. Асуудлуудыг таньж мэдэхэд чинь Би тусална, гэхдээ тэдгээрийг шийдвэрлэх нь та нараас хамаардаг.

Бусдыг сэжиглэдэггүй хүмүүсийг Би маш их үнэлдэг ба үнэнийг дуртайяа хүлээн зөвшөөрдөг хүмүүс Надад таалагддаг; ийм хоёр төрлийн хүмүүсийг Би асар их халамжилна, учир нь Миний нүдээр бол тэд үнэнч хүмүүс билээ. Хэрвээ чи ов мэхтэй бол бүх хүн, бүх хэрэг явдалд сэрэмжилж, сэжиглэж хандах бөгөөд тиймээс Надад итгэх итгэл чинь хардлагын суурин дээр үндэслэнэ. Ийм итгэлийг Би хэзээ ч хүлээн зөвшөөрч чадахгүй. Жинхэнэ итгэлгүй болохоор чамд жинхэнэ хайр бүр ч байдаггүй. Хэрвээ чи Бурханд эргэлзэж, Түүний талаар хүссэнээрээ боддог бол гарцаагүй хамгийн зальтай хүн юм. Бурхан хүнтэй адил байж чадах эсэхийг чи таамагладаг: уучилшгүй нүгэлтэй, явцуу сэтгэлтэй, шударга бус, үндэслэлгүй, шударга ёсны мэдрэмж дутмаг, муу арга заль хэрэглэдэг, дотуур тамиртай, зальхай, ёрын муу, харанхуйд дуртай гэх мэт. Хүмүүс ийм бодолтой байдгийн шалтгаан нь тэдэнд Бурханы талаарх өчүүхэн төдий ч мэдлэг байдаггүйгээс болдог бус уу? Тийм итгэл нь нүглээс өөрцгүй! Түүнчлэн, Миний таалалд нийцдэг хүмүүс бол яг нарийндаа бялдууч, зусарчид бөгөөд ийм чадвар дутмаг хүмүүсийг Бурханы гэрт ч хүлээн авахгүй, тэд тэнд хөлөө олохгүй гэж итгэдэг хүмүүс ч бий. Энэ олон жилийн турш эзэмшсэн мэдлэг чинь энэ үү? Та нарын олж авсан зүйл энэ үү? Миний талаарх та нарын мэдлэг зөвхөн ийм буруу ойлголтоор зогсдоггүй; Бурханы Сүнсийг доромжилж, Тэнгэрийг гутаадаг чинь үүнээс ч дор. Ийм учраас, та нарынх шиг ийм итгэл та нарыг Надаас улам холдуулж, Намайг илүү их эсэргүүцэхэд хүргэнэ гэж Би хэлдэг. Олон жилийнхээ ажлаар та нар олон үнэнийг харсан боловч Миний чих юу сонссоныг та нар мэдэх үү? Та нараас хэр олон нь үнэнийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна вэ? Та нар үнэний төлөө төлөөс төлөхөд бэлэн гэж бүгдээрээ итгэдэг ч хэд чинь үнэний төлөө үнэхээр зовсон бэ? Зүрх сэтгэлд чинь зөв шударга бус байдал л байдаг учраас та нар, хэн ч байсан хамаагүй хүн бүр зальтай, шударга бус гэж бодоод, бие махбодтой болсон Бурхан ч гэсэн хэвийн хүнтэй адилаар нинжин сэтгэлгүй, өр зөөлөн хайргүй байж чадна гэж ч итгэхэд хүрдэг. Үүнээс ч илүүтэйгээр, эрхэм дээд ёс жудаг, өршөөнгүй, өр зөөлөн уг чанар тэнгэр дэх Бурханд л оршдог гэж та нар итгэдэг. Тийм ариун хүн оршин байдаггүй бөгөөд зөвхөн харанхуй, ёрын муу л газар дээр ноёлдог, харин Бурхан бол хүмүүсийн сайн, сайхныг гэх хүсэл эрмэлзлээ даатгадаг зүйл, хүний зохиосон үлгэр домгийн нэгэн юм гэж та нар итгэдэг. Та нарын оюун ухаанд, тэнгэр дэх Бурхан бол маш шулуун шударга, зөвт, агуу, шүтэн мөргөж, бишрэхүйц байдаг; харин газар дээрх энэ Бурхан нь тэнгэр дэх Бурханы орлогч, багаж хэрэгсэл төдий байдаг. Энэ Бурхан нь тэнгэр дэх Бурхантай эн тэнцүү байж болохгүй, Түүнтэй зэрэгцүүлэн үзэж бүр ч болохгүй гэж та нар итгэдэг. Бурханы агуу байдал болон нэр хүндийн тухайд гэвэл тэдгээр нь тэнгэр дэх Бурханы алдар сууд харьяалагддаг, харин хүний уг

чанар болон завхралын тухайд бол, тэдгээр нь газар дээрх Бурханд ч байдаг шинж чанар юм. Тэнгэр дэх Бурхан мөнхөд сүрлэг байдаг байхад газар дээрх Бурхан мөнхөд ялихгүй, сул дорой, чадваргүй байдаг. Тэнгэр дэх Бурхан сэтгэл хөдлөлд автдаггүй, зөвхөн зөвт байдалтай байдаг, харин газар дээрх Бурханд хувиа хичээсэн сэдэл л байдаг ба ямар ч шударга байдал, эрүүл ухаан байдаггүй. Тэнгэр дэх Бурханд өчүүхэн төдий ч шударга бус зан байдаггүй, мөнхөд итгэмжит байдаг бол газар дээрх Бурханд шударга бус тал үргэлж байдаг. Тэнгэр дэх Бурхан хүнийг халуун дотноор хайрладаг байхад газар дээрх Бурхан хүнийг хангалтгүй халамжилдаг, тэр ч бүү хэл хүнийг бүрмөсөн үл ойшоодог. Ийм андуу ташаа мэдлэг та нарын зүрх сэтгэлд удаан хадгалагдсан ба ирээдүйд ч гэсэн бас үүрд хадгалагдах байх. Та нар шударга бус хүний байр сууриас Христийн бүх үйл хэргийг авч үздэг ба хорон муу хүний өнцгөөс Түүний бүх ажил, ялгамж чанар, мөн чанарыг үнэлдэг. Та нар ноцтой алдаа гаргасан ба өмнөх үеийнхнийхээ хэзээ ч хийж байгаагүй зүйлийг хийсэн. Өөрөөр хэлбэл, та нар тэргүүндээ титэмтэй, тэнгэр дэх сүрлэг Бурханд л үйлчилдэг бөгөөд үл үзэгдэхийн төдий маш ялимгүй Бурханд хэзээ ч санаа тавьдаггүй. Энэ нь та нарын нүгэл биш гэж үү? Энэ нь Бурханы зан чанарын эсрэг зөрчлийн чинь сонгодог жишээ биш гэж үү? Та нар тэнгэр дэх Бурханыг шүтэн мөргөдөг. Та нар сүрлэг дүр төрхийг биширч, уран үгээрээ ялгарсан хүмүүсийг хүндэлдэг. Гарыг чинь эд баялгаар дүүргэдэг Бурханд дуртайяа захирагдаж, хүсэл бүрийг чинь биелүүлж чадах Бурханыг ихэд хүсэмжилдэг. Чиний шүтэн мөргөдөггүй Нэгэн бол сүрлэг биш энэ Бурхан; чиний үзэн яддаг цорын ганц зүйл бол хэний ч өндрөөр үнэлдэггүй энэ Бурхантай холбоотой байх явдал. Хийхийг хүсдэггүй цорын ганц зүйл чинь чамд сохор зоос ч өгч байгаагүй энэ Бурханд үйлчлэх явдал бөгөөд Өөрийг нь хүсэн эрмэлзэхэд чамайг хүргэж чаддаггүй Нэгэн бол энэхүү тааламжит бус Бурхан билээ. Энэ Бурхан нь мэдлэгийн хүрээгээ тэлж, үнэт эрдэнэс олсон мэт санагдах боломжийг чамд олгож чадахгүй, хүсдэг зүйлийг чинь биелүүлж бүр ч чадахгүй. Тэгвэл чи яагаад Түүнийг дагадаг юм бэ? Чи иймэрхүү асуултуудыг бодож үзэж байсан уу? Чиний хийдэг зүйл энэ Христийг гомдоогоод зогсохгүй, үүнээс ч илүүтэйгээр тэнгэр дэх Бурханыг гомдоодог. Энэ нь Бурханд итгэх итгэлийн чинь зорилго биш гэж Би бодож байна!

Та нар Бурханыг баярлуулахыг хүсэн эрмэлздэг мөртөө Бурханаас хол байдаг. Энд ямар асуудал байна вэ? Та нар Түүний үгийг хүлээн зөвшөөрдөг ч харьцалт, засалтыг нь хүлээн зөвшөөрдөггүй, Түүний зохицуулалт бүрийг хүлээн зөвшөөрч, Түүнд бүрэн итгэлтэй байж бүр ч чаддаггүй. Тэгвэл энд ямар асуудал байна вэ? Эцсийн дүндээ, та нарын итгэл бол хоосон өндөгний хальс бөгөөд ангаахай бий болгож хэзээ ч чадахгүй. Учир нь итгэл чинь та нарт үнэнийг авчраагүй, эсвэл амийг өгөөгүй, харин ч оронд нь дэмжлэг, найдварын хуурмаг мэдрэмжийг та нарт өгсөн. Бурханд итгэх итгэлийн чинь зорилго үнэн ба амь биш, харин дэмжлэг, найдварын энэхүү мэдрэмж юм. Тиймээс, Бурханд итгэх итгэлийн замнал чинь бялдууч зан, ичгүүргүй байдлаар дамжуулан Бурханд тал засахаар хичээдгээс өөр юу ч биш

бөгөөд үүнийг яавч жинхэнэ итгэл хэмээн үзэж болохгүй гэж Би хэлдэг. Ийм итгэлээс яаж ангаахай төрж болох юм бэ? Өөрөөр хэлбэл, ийм итгэл юу биелүүлж чадах юм бэ? Бурханд итгэх итгэлийн чинь зорилго бол өөрийнхөө зорилгыг биелүүлэхэд Бурханыг ашиглах явдал юм. Цаашлаад энэ нь Бурханы зан чанарт халддагийн чинь баримт биш гэж үү? Та нар тэнгэр дэх Бурханы оршин тогтнолд итгээд, газар дээрх Бурханы оршин тогтнолыг үгүйсгэдэг ч Би та нарын үзэл бодлыг хүлээн зөвшөөрдөггүй; ул суурьтай байж, газар дээрх Бурханд үйлчилдэг хүмүүсийг л Би сайшаадаг, харин газар дээрх Христийг огт хүлээн зөвшөөрдөггүй хүмүүсийг хэзээ ч сайшаадаггүй. Тийм хүмүүс тэнгэр дэх Бурханд хэчнээн үнэнч байх нь хамаагүй, эцэстээ тэд хорон санаатныг шийтгэдэг Миний гараас зайлахгүй. Энэ хүмүүс бол хорон санаатнууд; тэд бол Бурханыг эсэргүүцдэг бөгөөд Христийг хэзээ ч дуртайяа дуулгавартай дагадаггүй ёрын муу хүмүүс юм. Мэдээж тэдний тоонд Христийг мэддэггүй, цаашлаад хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс багтдаг. Тэнгэр дэх Бурханд үнэнч байгаа цагт Христэд хүссэнээрээ хандаж болно гэж чи итгэдэг үү? Тэгэх нь буруу! Чи Христийг мэдэхгүй бол тэнгэр дэх Бурханыг мэдэхгүй. Тэнгэр дэх Бурханд хэчнээн үнэнч байх чинь хамаагүй энэ нь зүгээр л нэг хоосон яриа, хуурамч дүр эсгэлт юм, учир нь газар дээрх Бурхан нь үнэнийг хүлээн авч, илүү гүнзгий мэдлэгтэй болоход хүнд ач тустайгаар үл барам, хүнийг яллаж, улмаар хорон санаатнуудыг шийтгэх баримтуудыг цуглуулахад бүр ч их ач тустай. Чи энд байгаа ашиг тустай болон хор хөнөөлтэй үр дүнг ойлгов уу? Чи тэдгээрийг туулсан уу? Та нар энэ үнэнийг аль болох хурдан ойлгоосой гэж Би хүсэж байна: Бурханыг мэдэхийн тулд чи тэнгэр дэх Бурханыг мэдээд зогсохгүй, хамгийн чухал нь газар дээрх Бурханыг мэдэх ёстой. Аль нь чухал талаар бүү будил, эсвэл хоёрдогч зүйлээр гол зүйлийг бүү орлуул. Зөвхөн ийм маягаар л чи Бурхантай үнэхээр сайн харилцаатай болж, Бурхантай илүү ойр болж, зүрх сэтгэлээ Түүнд улам ойртуулж чадна. Хэрвээ чи олон жил итгэлтэй байж, Надтай удаан хугацаанд холбоотой байсан ч Надаас хол хэвээр үлдсэн бол, чи Бурханы зан чанарт байнга халдаж байсан байж таарна, мөн чиний төгсгөлийг тооцоолоход маш хэцүү байх болно гэж Би хэлнэ. Надтай олон жил харилцаатай байсан чинь чамайг хүн чанартай, үнэнтэй хүн болгон өөрчлөөгүй, харин ч муу арга зам чинь чиний уг чанарт шингэж, чи хоёр дахин их зантай болоод зогсохгүй Миний талаарх буруу ойлголт чинь ч бас ихсэж, улмаар чи Намайг хань хамсаатан шигээ үзэж эхэлбэл өвчин эмгэг чинь өнгөцхөн биш, харин ясанд чинь нэвчсэн байна гэж Би хэлнэ. Тэгээд чи, оршуулгын чинь бэлтгэл ажил хийгдэхийг л хүлээх үлдэнэ. Тэр үед чиний Бурхан болохыг Надаас гуйж гувших хэрэггүй, учир нь чи үхэх ёстой нүгэл, уучилшгүй нүгэл үйлдсэн билээ. Би чамд өршөөл үзүүлж чадсан ч гэсэн, тэнгэр дэх Бурхан амийг чинь авахаар зүтгэнэ, учир нь Бурханы зан чанарын эсрэг халдсан чинь энгийн асуудал биш, харин уг чанартаа тун ноцтой юм. Цаг нь ирэхэд, чамд урьдчилан хэлээгүй гэж Намайг бүү буруутга. Энэ бүхэн нь ийм байх болно: Чи газар дээрх Бурхан буюу Христэд эгэл жирийн хүн мэт хандах үедээ, өөрөөр хэлбэл, энэ Бурхан нь хүнээс

өөрцгүй гэж итгэх үедээ мөхөх болно. Энэ нь та бүхэнд өгөх цорын ганц сануулга минь билээ.

ТУН НОЦТОЙ АСУУДАЛ: УРВАЛТ 1

Миний ажил тун удахгүй дуусна. Хамт өнгөрүүлсэн он жилүүд тэвчихийн аргагүй дурсамж болжээ. Би үгээ тасралтгүй давтаж, шинэ ажлаа зогсолтгүй үргэлжлүүлсэн. Мэдээж, Миний зөвлөгөө бол Миний хийдэг ажил болгоны чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Миний зөвлөгөөгүйгээр та нар бүгд төөрөлдөж, бүр яахаа ч мэдэхээ болих байсан. Одоо Миний ажил дуусах дөхөж, сүүлчийн шатандаа байна. Би зөвлөгөө өгөх ажил хийхийг, өөрөөр хэлбэл, та нарт сонсгох зөвлөмж чанартай хэдэн үг хэлэхийг хүссээр байна. Та нар Миний уйгагүй хүчин чармайлтыг хий дэмий үрэхгүй байж, түүнээс ч илүүтэйгээр, хичээнгүйлэн санаа тавьж буйг минь ойлгож, Миний үгийг хүн байхын үндэс суурь хэмээн үзээсэй л гэж Би найдаж байна. Та нарын сонсоход бэлэн үг энэ мөн ч бай, биш ч бай, та нарын дуртайяа хүлээн авах, эсвэл таагүй хүлээн авах үг мөн ч бай, биш ч бай, та нар нухацтай хандах ёстой. Эс тэгвэл, үл тоомсорлосон, хайхрамжгүй зан чанар, араншин чинь Намайг маш их гонсойлгож, үнэндээ Миний зэвүүцлийг төрүүлнэ. Та бүгд Миний үгийг ахин дахин, магадгүй бүр цээжээр мэддэг болтлоо хэдэн мянган удаа уншина гэж Би ихэд найдаж байна. Ийм маягаар л та нар Миний итгэл найдварыг нураахгүй байж чадна. Гэхдээ та нарын нэг нь ч одоо ингэж амьдардаггүй. Эсрэгээрээ та нар бүгд ханатлаа идэж, уудаг садар самуун амьдралд ташуурдаг бөгөөд та нарын нэг нь ч Миний үгийг ашиглан, зүрх сэтгэл, сүнсээ баяжуулдаггүй. Ийм учраас, Би хүн төрөлхтний жинхэнэ төрхийг ингэж дүгнэсэн: Хүн хэдийд ч Надаас урваж чадна, Миний үгэнд туйлын үнэнч байж чадах хэн ч үгүй.

“Хүнийг Сатан маш их ялзруулсан тул хүн төрхтэй байхаа больсон.” Одоо ихэнх хүн энэ хэллэгийг тодорхой хэмжээнд хүлээн зөвшөөрдөг. Миний хэлж буй “хүлээн зөвшөөрөх” гэдэг нь жинхэнээсээ мэдэхтэй харьцуулахад зүгээр нэг өнгөцхөн хүлээн зөвшөөрөх явдал төдий учраас Би ингэж хэлдэг. Та нарын нэг нь ч өөрсдийгөө үнэн зөвөөр үнэлж, бас нэгд нэггүй шинжилж чадахгүй тул Миний үгэнд эргэлзсэн хэвээр үлддэг. Гэхдээ та нарын дотор оршдог хамгийн ноцтой асуудлыг тайлбарлахын тулд Би энэ удаад баримт ашиглаж байна. Тэрхүү асуудал нь урвалт юм. Та нар бүгд “урвалт” гэдэг үгийг мэднэ, учир нь нөхөр нь эхнэрээсээ урвах, эхнэр нь нөхрөөсөө урвах, хүү нь эцгээсээ урвах, охин нь эхээсээ урвах, боол нь эзнээсээ урвах, найзууд нэг нэгнээсээ урвах, хамаатнууд нэг нэгнээсээ урвах, худалдагчид худалдан авагчдаасаа урвах гэх мэтчилэн ихэнх хүн бусдаас урвах ямар нэгэн зүйл хийж байсан. Энэ бүх жишээ урвалтын мөн чанарыг агуулдаг. Товчхондоо, урвалт бол амлалтаасаа буцаж, ёс суртахууны зарчмыг зөрчих буюу хүний ёс зүйд харшлах үйлдэл хийж, хүн чанараа алдсаныг харуулдаг нэг төрлийн

зан авир юм. Чи хэзээ нэгэн цагт хэн нэгнээс урвах зүйл хийснээ санадаг ч бай эсвэл урьд нь олон удаа бусдаас урвасан ч бай хамаагүй, ерөнхийдөө энэ хорвоод төрсөн хүн болохын хувьд үнэнээс урвахтай адил ямар нэгэн зүйл хийсэн байх болно. Чи эцэг эх, найз нөхдөөсөө урвах чадвартай тул бусдаас урвах, түүгээр ч үл барам Надаас урваж, Миний үзэн яддаг зүйлсийг хийх чадвартай. Өөрөөр хэлбэл урвалт нь ёс суртахуунгүй өнгөцхөн үйлдэл төдий биш харин үнэнтэй зөрчилддөг зүйл юм. Энэ нь яг нарийндаа хүн төрөлхтөн Намайг эсэргүүцэж, Надад дуулгаваргүй байхын эх сурвалж юм. Ийм учраас Би үүнийг дараах өгүүлбэрээр нэгтгэн дүгнэлээ: Урвалт бол хүний уг чанар бөгөөд энэ уг чанар нь Надтай нийцдэг хүн бүрийн томоохон дайсан юм.

Надад туйлын дуулгавартай байж чадахгүй үйлдэл бол урвалт. Надад үнэнч байж чадахгүй үйлдэл бол урвалт. Намайг хуурч, Намайг мэхлэхийн тулд худал хэлэх нь урвалт. Олон үзэл өвөрлөж, тэдгээрийг хаа сайгүй тараах нь урвалт. Миний гэрчлэл, ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй байх нь урвалт. Зүрх сэтгэлээрээ Надаас хол байх үедээ хуурамч инээмсэглэл тодруулах нь урвалт. Эдгээр нь бүгд та нарын үргэлж хийж чаддаг байсаар ирсэн урвалтын үйлдлүүд бөгөөд та нарын дунд түгээмэл байдаг. Та нарын хэн нь ч үүнийг асуудал гэж бодохгүй байж болох ч, Би тэгж бодохгүй байна. Хүн Надаас урвах нь Миний хувьд ялихгүй асуудал биш, үүнийг хайхрахгүй орхиж Би яавч чадахгүй. Одоо Намайг та нарын дунд ажиллаж байхад та нар ингэж авирладаг—та нарыг харж хандах хэн ч байхгүй болох өдөр ирвэл та нар өөрсдийгөө жижигхэн уулынхаа хаан нь гэж тунхагласан дээрэмчин адил байх бус уу? Тийм зүйл болж, гай гамшиг тарьсан хойно чинь хэн засаж залруулах вэ? Зарим урвасан үйлдлүүдийг өөрсдийнхөө байнгын үйлдэл биш, ердөө тохиолдлын хэрэг хэмээн та нар бодож, нэр төрийг чинь гутаах хэмжээний ноцтойгоор авч хэлэлцэх хэрэггүй гэж үздэг. Хэрвээ та нар үнэхээр тэгж боддог бол эрүүл ухаан дутмаг байна. Тэгж бодох нь тэрслүү байдлын үлгэр жишээ, нийтлэг шинж юм. Хүний уг чанар бол түүний амь; амьд үлдэхийн тулд түшиглэдэг зарчим нь бөгөөд хүн үүнийг өөрчилж чадахгүй. Урвалтын уг чанарыг жишээ болгон аваад үз. Хэрвээ чи хамаатан садан, найз нөхдөөсөө урвах ямар нэгэн зүйл хийж чаддаг бол энэ нь амийн чинь нэг хэсэг, төрөлх уг чанар чинь гэдэг нь нотлогддог. Энэ бол хэний ч үгүйсгэж чадахгүй зүйл. Жишээлбэл, хэрвээ хүн бусдаас хулгайлах дуртай бол заримдаа хулгай хийж, заримдаа хийдэггүй байсан ч “хулгайлах дуртай” байх нь түүний амийн нэг хэсэг болдог. Тэд хулгайлсан ч бай, үгүй ч бай, хулгай хийх нь зүгээр л нэг төрлийн үйлдэл гэдгийг энэ нь баталж чадахгүй. Харин ч хулгай хийх нь тэдний амийн нэг хэсэг, өөрөөр хэлбэл, тэдний уг чанар гэдгийг энэ нь нотолдог. Зарим хүн: Тэдний уг чанар нь ийм юм бол сайхан зүйлс харахаараа тэд заримдаа яагаад хулгайлдаггүй юм бэ? гэж асууна. Хариулт нь маш энгийн. Тэдэнд хулгайлахгүй байх маш олон шалтгаан бий. Бусдыг харж байхад авч явахад хэтэрхий том зүйл байх ч юм уу, эсвэл тохиромжтой цаг нь биш байх, хэтэрхий үнэтэй зүйл байх, хэт хатуу чанга харуул хамгаалалттай байх, магадгүй тэд

үүнийг онцгойлон сонирхдоггүй, эсвэл ямар хэрэгтэйг нь мэдэхгүй байх гэх мэт шалтгаанаар тэд хулгайлахгүй байж болно. Энэ бүх шалтгаан байж болно. Гэхдээ юм хулгайлсан ч бай, үгүй ч бай, тэдэнд ийм бодол хоромхон зуур төрөөд өнгөрдөг гэж нотлох аргагүй. Харин ч эсрэгээрээ энэ бол засаж сайжруулахад бэрх уг чанарынх нь нэг хэсэг мөн. Ийм хүн ганцхан удаа хулгай хийгээд сэтгэл нь ханадаггүй; ямар нэгэн сайхан зүйлтэй таарах юм уу, тохиромжтой нөхцөл байдал гарах бүрд бусдын эд зүйлийг өөрийн болгох бодол төрдөг. Тийм учраас ийм бодлын эх үүсвэр нь зүгээр л хаяа нэг гарч ирдэг зүйл биш, харин тухайн хүний уг чанарт нь байдаг гэж Би хэлдэг.

Хэн ч үг, үйлдлээрээ жинхэнэ төрхөө илэрхийлж чадна. Энэхүү жинхэнэ төрх нь мэдээж тэдний уг чанар юм. Хэрвээ чи булзааруулж ярьдаг хүн бол булзамхай уг чанартай. Хэрвээ уг чанар чинь зальхай бол чи зальжин авирладаг бөгөөд хүмүүс чамд тун амархан мэхлэгдэнэ. Хэрвээ уг чанар чинь хорлонтой бол үгийг чинь сонсоход таатай байж болох ч үйлдэл чинь олиггүй заль мэхийг чинь далдалж чадахгүй. Хэрвээ уг чанар чинь залхуу бол хэлдэг үг бүр чинь хааш яаш, залхуу байдлынхаа улмаас хариуцлагаас зайлсхийх зорилготой байдгийн дээр үйлдэл чинь удаан, хааш яаш, мөн үнэнийг далдлахдаа нэлээд сурамгай байдаг. Хэрвээ чиний уг чанар уян зөөлөн бол үг чинь ухаалаг, үйлдэл чинь ч бас үнэнтэй сайтар нийцнэ. Хэрвээ уг чанар чинь үнэнч бол үг чинь гарцаагүй чин сэтгэлийн, үйлдэл чинь ул суурьтай, эзнийхээ санааг зовоох юм байдаггүй. Хэрвээ уг чанар чинь тачаангуй, эсвэл мөнгөнд шунадаг бол зүрх сэтгэл чинь үргэлж ийм зүйлээр дүүрэн байж, хүмүүсийн амархан мартахааргүй, зэвүүцлийг нь төрүүлэхүйц гажууд, ёс суртахуунгүй үйлийг чи өөрийн эрхгүй үйлдэнэ. Миний хэлсэнчлэн, хэрвээ чи урвагч уг чанартай бол үүнээс өөрийгөө салгаж бараг чадахгүй. Чи бусдад буруу зүйл хийж байгаагүй болохоор урвагч уг чанар байхгүй гэж азад бүү найд. Хэрвээ ингэж бодож байвал чи үнэхээр дургүй хүрмээр юм. Намайг ярих болгонд Миний бүх үг ганцхан хүн, эсвэл ганцхан төрлийн хүнд бус, харин бүх хүнд чиглэдэг. Надаас нэг зүйл дээр урваагүй гэдэг чинь аливаа нэг зүйл дээр урваж чадахгүй гэдгийг чинь батлахгүй. Гэрлэлтэд нь бэрхшээл тохиолдоход зарим хүн үнэнийг эрж хайх итгэлээ алддаг. Зарим хүн гэр бүл салалтын үеэр Надад үнэнч байх үүргээсээ татгалздаг. Зарим хүн хоромхон зуурын баяр хөөр, сэтгэлийн таашаалыг эрж хайж Намайг орхидог. Зарим хүн гэрэлд амьдарч, Ариун Сүнсний ажлын баяр бахдалыг хүртсэний оронд харанхуй хавцал руу унахыг илүүд үздэг. Зарим хүн эд хөрөнгийн шуналаа хангахын төлөө найз нөхдийн зөвлөгөөг үл ойшоодог бөгөөд одоо ч алдаагаа хүлээн зөвшөөрч, замналаа өөрчилж чаддаггүй. Зарим хүн Надаар хамгаалуулах л гэж Миний нэрийн дор түр зуур амьдардаг байхад зарим нь амьдралд шунан, үхлээс эмээхийн эрхээр Надад жаахныг зориулдаг. Энэ болон бусад ёс суртахуунгүй үйлдэл, түүнчлэн ёс жудаггүй үйлдлүүд нь зүрх сэтгэлийнхээ гүнд Надаас аль хэдийн урвасан хүмүүсийн үйлдлүүд бус уу? Мэдээж, хүмүүс Надаас урвахаар урьдаас төлөвлөдөггүй гэдгийг Би мэднэ; тэдний урвалт бол уг

чанарынх нь төрөлхийн илчлэл юм. Хэн ч Надаас урвахыг хүсдэггүй, Надаас урвах ямар нэгэн зүйл хийснээсээ болоод хэн ч аз жаргалтай байдаггүй. Харин ч тэд айн чичирдэг, тийм биз дээ? Тэгэхээр та нар эдгээр урвалтыг хэрхэн засаж залруулах, одоогийн нөхцөл байдлыг хэрхэн өөрчлөх талаар бодож байна уу?

ТУН НОЦТОЙ АСУУДАЛ: УРВАЛТ 2

Хүний уг чанар Миний мөн чанараас нэлээд өөр, учир нь хүний завхарсан уг чанар бүхэлдээ Сатанаас үүсэлтэй; хүний уг чанарыг Сатан боловсруулж, ялзруулсан юм. Өөрөөр хэлбэл, хүн Сатаны ёрын муу, үзэшгүй муухай байдлын нөлөөн дор амьдардаг. Хүн үнэний ертөнцөд юм уу ариун орчинд өсөж торнидоггүй, гэрэлд бүр ч амьдардаггүй. Тиймээс, ямар ч хүн төрөлхөөсөө уг чанар дотроо үнэнтэй байх боломжгүй, мөн Бурханаас эмээж, Бурханд дуулгавартай байх мөн чанартай төрж бүр ч чадахгүй. Эсрэгээрээ хүмүүс Бурханыг эсэргүүцдэг, Бурханд дуулгаваргүй, үнэнийг хайрладаггүй уг чанартай байдаг. Энэ уг чанар бол Миний ярихыг хүсэж байгаа асуудал—урвалт юм. Урвалт бол хүн бүрийн Бурханыг эсэргүүцэх эсэргүүцлийн эх сурвалж мөн. Энэ нь Надад биш, харин зөвхөн хүнд л байдаг асуудал билээ. Зарим хүн ингэж асууна: Бүх хүн Христтэй адил ертөнцөд амьдардаг байж яагаад бүх хүнд Бурханаас урвадаг уг чанар байхад Христэд байдаггүй юм бэ? Энэ бол та нарт тодорхой тайлбарлаж өгөх ёстой асуудал юм.

Хүн төрөлхтний оршин тогтнолын үндэс нь сүнс удаа дараа төрлөө олох явдал юм. Өөрөөр хэлбэл, хүний сүнс дахин төрлөө олоход хүн болгон махан бие бүхий хүний амийг олж авдаг. Хүний бие төрсний дараа, махан бие нь эцэстээ хязгаартаа хүртэл буюу сүнс бүрхүүлээ орхин явах сүүлчийн мөч хүртэл амь нь үргэлжилдэг. Энэ үйл явц нь хүний сүнс удаа дараа ирж, буцахын хэрээр ахин дахин давтагдаж, ийнхүү хүн төрөлхтний оршин тогтнолыг хадгалж байдаг. Махан биеийн амь нь бас хүний сүнсний амь бөгөөд хүний сүнс нь хүний махан биеийн оршин тогтнолыг дэмжиж байдаг. Өөрөөр хэлбэл, хүн нэг бүрийн амь сүнснээс ирдэг бөгөөд амь нь махан биед төрөлхөөсөө байдаггүй. Тиймээс хүний уг чанар махан биеэс бус, харин сүнснээс гаралтай. Сатаны уруу таталт, гай зовлон, завхралыг хэрхэн туулснаа хүн бүрийн сүнс нь л мэддэг. Хүний махан бие эдгээрийг мэдэх аргагүй. Тиймээс, хүн төрөлхтөн өөрийн эрхгүй улам харанхуй, улам бузар, улам ёрын муу болж, харин хүн Бид хоёрын хоорондох зай улам ихсээд, хүн төрөлхтний хувьд амьдрал улам харанхуй болдог. Сатан хүн төрөлхтний сүнсийг атгаж байдаг тул мэдээж хүний махан биеийг ч бас эзлэн авсан. Ийм махан бие, ийм хүн төрөлхтөн яаж Бурханыг эсэргүүцэхгүй байж чадах юм бэ? Тэд Түүнтэй төрөлхөөсөө нийцэлтэй байж яаж чадах юм бэ? Сатан Надаас урвасан учраас Би түүнийг агаар луу доош хаясан. Тэгвэл хүмүүс яаж үүнээс ангижирч чадах юм бэ? Ийм учраас урвалт бол хүний уг чанар юм. Та нар энэ шалтгааныг ойлгомогцоо Христийн мөн

чанарт ч бас тодорхой хэмжээгээр итгэх учиртай гэж Би итгэж байна. Бурханы Сүнсний өмссөн махбод нь Бурханы Өөрийнх нь махбод билээ. Бурханы Сүнс бол эрхэм дээд; Тэрээр төгс хүчит, ариун, зөвт билээ. Үүний адилаар Түүний махбод ч бас эрхэм дээд, төгс хүчит, ариун, зөвт юм. Ийм махбод нь зөвт, хүн төрөлхтөнд ач тустай зүйлийг, мөн ариун, алдар суутай, сүр хүчтэй зүйлийг л хийж чаддаг; Тэрээр үнэн, ёс суртахуун, шударга ёсыг зөрчдөг юуг ч хийж чадахгүй, Бурханы Сүнснээс урвах ямар нэг зүйлийг хийж бүр ч чадахгүй. Бурханы Сүнс ариун тул Түүний махбодыг Сатан завхруулах аргагүй; Түүний махбод хүний махан биеэс өөр мөн чанартай. Учир нь, Сатан Бурханыг биш, хүнийг завхруулсан; Сатан Бурханы бие махбодыг завхруулж яавч чадахгүй. Тиймээс хүн, Христ хоёр ижил газар амьдран суудаг баримтаас үл хамааран зөвхөн хүнийг л Сатан эзэмдэж, ашиглаж, бас урхиддаг. Үүнээс ялгаатай нь Христ үүрд Сатаны завхралд авташгүй, учир нь Сатан хамгийн өндөр газарт хүрч, Бурханд ойртон очиж хэзээ ч чадахгүй. Өнөөдөр, Сатаны завхруулсан хүн төрөлхтөн л Надаас урвадаг гэдгийг та нар бүгд ойлгох ёстой. Урвалт нь Христтэй өчүүхэн ч хамаагүй асуудал юм.

Сатаны завхруулсан бүх сүнс Сатаны эзэмшилд олзлогдсон байдаг. Христэд итгэдэг хүмүүс л тусгаарлагдаж, Сатаны баазаас аврагдаж, өнөөдрийн хаанчлалд хүргэгдсэн. Энэ хүмүүс цаашид Сатаны нөлөөн дор амьдрахгүй. Тэгсэн ч гэсэн, хүний уг чанар махан биед нь үндэслэсэн хэвээр байдаг, өөрөөр хэлбэл, та нарын сүнс аврагдсан ч уг чанар чинь урьдынх шигээ хэвээр байдаг бөгөөд Надаас урвах магадлал чинь зуун хувь хэвээр үлдэнэ. Тийм учраас, та нарын уг чанар хэтэрхий гуйвшгүй тул Миний ажил ийм удаан үргэлжилдэг. Одоо та нар үүргээ биелүүлэхдээ чадлынхаа хэрээр зовлон бэрхшээл туулж байгаа ч дор бүрнээ Надаас урваж, Сатаны эзэмшил рүү, түүний бааз руу буцаж, хуучин амьдралдаа эргэн орж чадна—энэ бол үгүйсгэхийн аргагүй баримт юм. Тэр үед та нар одоогийнх шигээ бага зэргийн хүн чанартай, хүний төрхтэй байх боломжгүй болно. Ноцтой тохиолдолд, та нар устгагдана, түүнээс гадна хэзээ ч дахин төрлөө олохгүйгээр үүрд мөхөж, хатуу шийтгүүлнэ. Энэ бол та нарын өмнө тулгарсан асуудал юм. Би нэгдүгээрт, ажлаа талаар болгохгүйн тулд, хоёрдугаарт, та нарыг бүгдийг нь гэрэл гэгээтэй өдрүүдэд амьдруулахын тулд ийм маягаар та нарт сануулж байна. Үнэн хэрэгтээ Миний ажил талаар болох эсэх нь гол асуудал биш. Та нар аз жаргалтай амьдрал, гайхалтай сайхан ирээдүйтэй байж чадах нь гол чухал юм. Миний ажил бол хүмүүсийн сүнсийг аврах ажил. Хэрвээ чиний сүнс Сатаны гарт орвол, бие чинь амар тайван амьдрахгүй. Хэрвээ Би чиний биеийг хамгаалж байгаа бол сүнс чинь Миний халамжин дор байх нь гарцаагүй. Хэрвээ Би чамайг үнэхээр үзэн ядвал чиний сүнс болон бие тэр даруй Сатаны гарт орно. Тэр үед нөхцөл байдал чинь ямар байхыг чи төсөөлж чадах уу? Хэрвээ нэг л өдөр та нар Миний үгийг ойлгохгүй байвал Би уураа бүрэн гартал бүгдийг чинь Сатанд гардуулан өгч, шаналгаат тарчлаанд өртүүлнэ, эсвэл Надаас урвадаг зүрх сэтгэл чинь хэзээ ч өөрчлөгдөөгүй байх учраас засаршгүй хүмүүс та нарыг Би биечлэн шийтгэнэ.

Одоо та нар, дотор чинь Надаас урвах урвалт хэр их үлдсэнийг мэдэхийн тулд өөрсдийгөө аль болох хурдан шинжлэх ёстой. Та нарын хариуг Би тэсэн ядан хүлээж байна. Надтай харьцахдаа хуумгай бүү бай. Би хэзээ ч хүмүүстэй тоглоом тоглодоггүй. Хэрвээ Би ямар нэг юм хийнэ гэж хэлсэн бол гарцаагүй хийнэ. Би та нар дор бүрнээ Миний үгийг нухацтай авч үздэг хүмүүс байж, тэдгээрийг шинжлэх ухааны зөгнөлт зохиол мэт үзэхгүй гэдэгт Би найдаж байна. Би та нараас төсөөлөл биш, бодитой үйлдэл л хүсдэг. Дараа нь та нар Миний энэ асуултуудад хариулах ёстой:

1. Хэрвээ чи үнэхээр үйлчлэл үзүүлэгч мөн бол хайнга, сөрөг байдлын ямар ч элементгүйгээр Надад үнэнчээр үйлчлэл үзүүлж чадах уу?
2. Чамайг хэзээ ч үнэлж байгаагүйг минь олж мэдэх юм бол чи насан туршдаа үлдээд, Надад үйлчлэл үзүүлсээр байж чадах уу?
3. Чамайг ихээхэн хичээл зүтгэл гаргасан ч гэсэн Би чамд тун хүйтэн хөндий хандсаар байвал анзаарагдалгүйгээр Миний төлөө үргэлжлүүлэн ажиллаж чадах уу?
4. Чамайг Миний төлөө зарлага гаргасны дараа Би ялихгүй хүсэлтийг чинь биелүүлдэггүй бол чи сэтгэлээр унаж, Надад урам хугарах уу, эсвэл бүр уурсан хилэгнэж, хараал зүхэл хашхирах уу?
5. Хэрвээ чи Надад үргэлж маш үнэнч байж, Намайг ихэд хайрлаж байсан ч өвчин зовлон, ядуурлын тарчлаан амсаж, найз нөхөд, төрөл төрөгсдөдөө орхигдох юм уу амьдралдаа өөр золгүй явдал туулбал Намайг гэх үнэнч зан, хайр чинь үргэлжилсээр байх уу?
6. Зүрх сэтгэлдээ төсөөлсөн зүйлээс чинь нэг нь ч Миний хийсэнтэй таардаггүй бол чи ирээдүйн замдаа хэрхэн алхах вэ?
7. Хэрвээ чи хүртэнэ гэж найдаж байсан зүйлийнхээ нэгийг нь ч хүлээн авч чадахгүй бол Миний дагалдагч хэвээр байж чадах уу?
8. Хэрвээ чи Миний ажлын зорилго, ач холбогдлыг хэзээ ч ойлгож байгаагүй бол дураараа шүүлт хийж, дүгнэлт гаргадаггүй дуулгавартай хүн байж чадах уу?
9. Намайг хүн төрөлхтөнтэй хамт байх зуур чи Миний хэлсэн бүх үг, хийсэн бүх ажлыг эрхэмлэн нандигнаж чадах уу?
10. Чи ямар нэг юм хүлээн авахгүй байсан ч гэсэн, насан туршдаа Миний төлөө зовоход бэлэн, Миний үнэнч дагалдагч байж чадах уу?
11. Миний төлөө чи ирээдүйн амьдралын замаа бодолцон үзэхгүй, төлөвлөхгүй, бэлдэхгүй байж чадах уу?

Эдгээр асуулт та нарт тавих Миний сүүлчийн шаардлагыг төлөөлдөг бөгөөд та нар бүгд Надад хариулт өгч чадна гэж Би найдаж байна. Чи эдгээр асуултын ганц, хоёрыг нь л биелүүлсэн бол үргэлжлүүлэн чармайх ёстой. Хэрвээ чи эдгээр шаардлагаас ганцыг нь ч биелүүлж чадахгүй бол гарцаагүй там руу хаягдах төрлийн хүн юм. Ийм хүмүүст Би нэмж юм хэлэх шаардлагагүй, учир нь тэд Надтай

нийцэж чадах хүмүүс яавч биш. Ямар ч нөхцөлд Надаас урваж чадах хүнийг Би яаж Өөрийн гэрт байлгаж чадах билээ? Ихэнх тохиолдолд Надаас мөн л урваж чадах хүмүүсийн тухайд бол Би өөр зохицуулалт хийхээсээ өмнө тэдний гүйцэтгэлийг ажиглана. Гэхдээ, ямар ч нөхцөл байдалд байсан бай, Надаас урваж чадах хүмүүсийг Би хэзээ ч мартахгүй; Би тэднийг сэтгэлдээ санаж, ёрын муу үйл хэрэгт нь хариу барих боломжийг хүлээнэ. Миний тавьсан шаардлагууд бол та нар өөрсдийгөө шалгах ёстой бүх асуудал юм. Та нар бүгд эдгээрийг нухацтай авч үзэн, Надтай хааш яаш харьцахгүй гэдэгт Би найдаж байна. Ойрын ирээдүйд Би та нарын өгсөн хариултыг Өөрийн шаардлагуудтай харьцуулан шалгана. Тэр үед Би та нараас өөр юу ч шаардахгүй, бас чин сэтгэлийн сануулга өгөхгүй. Оронд нь Би эрх мэдлээ хэрэгжүүлнэ. Үлдэх ёстой хүмүүс үлдэж, шагнуулах ёстой нь шагнуулж, Сатанд очих ёстой нь Сатанд өгөгдөж, хатуу шийтгүүлэх ёстой нь хатуу шийтгүүлж, мөхөх ёстой нь устгагдана. Ийнхүү Миний өдрүүдэд Намайг үймүүлэх нэг ч хүн байхаа болино. Чи Миний үгэнд итгэж байна уу? Залхаан цээрлүүлэлтэд итгэж байна уу? Намайг хуурч, Надаас урвадаг ёрын муу бүх хүнийг шийтгэнэ гэдэгт минь итгэдэг үү? Тэр өдөр удахгүй ирээсэй гэж чи хүсдэг үү, эсвэл дараа ирээсэй гэж хүсдэг үү? Чи шийтгэлээс үхтэлээ айдаг хүн үү, эсвэл шийтгэл хүлээх ёстой ч Намайг эсэргүүцэхийг илүүд үзэх хүн үү? Тэр өдөр ирэхэд чи баяр хөөр, инээд баясал дунд амьдрах уу, эсвэл уйлж, шүдээ хавирах уу гэдгээ төсөөлж чадах уу? Чи ямархуу төгсгөлтэй тулгарна гэж найдаж байна? Чи Надад зуун хувь итгэдэг үү, эсвэл зуун хувь эргэлздэг үү гэдгээ ер нь ноцтой бодож үзсэн үү? Үйлдэл, зан авир чинь ямар үр дагавар, төгсгөлд хүргэж болохыг чи ер нь нухацтай бодож байв уу? Миний бүх үг ээлж дараалан биелээсэй гэж чи үнэхээр хүсэж байна уу, эсвэл Миний үг ар араасаа биелнэ гэхээс үхтэлээ айж байна уу? Хэлсэн үгээ биелүүлэхийн тулд удахгүй явна гэдэгт минь чи итгэдэг бол үг, үйлдэлдээ хэрхэн хандах ёстой вэ? Хэрвээ чи Намайг яваасай гэж хүсдэггүй, Миний бүх үг шууд биелээсэй гэж хүсдэггүй бол ер нь яагаад Надад итгэдэг юм бэ? Чи яагаад Намайг дагаж байгаагаа үнэхээр мэдэж байна уу? Чи мэдлэгийн хүрээгээ л тэлэх зорилготой бол өөртөө ингэж төвөг удах шаардлагагүй. Хэрвээ ерөөгдөж, айсуй гамшгаас мултрахын төлөө бол чи яагаад биеэ авч явах байдалдаа санаа зовохгүй байгаа юм бэ? Миний шаардлагыг биелүүлж чадах эсэхээ өөрөөсөө яагаад асуухгүй байгаа юм бэ? Хожмын ерөөлийг хүртэх эрхтэй эсэхээ өөрөөсөө яагаад асуухгүй байгаа юм бэ?

ТА НАР ҮЙЛ ХЭРГЭЭ БОДОЛЦОЖ ҮЗЭХ УЧИРТАЙ

Өөрсдийгөө хангахын тулд та нар өдөр бүр Миний үгээс нэг хэсгийг хүртэж байх шаардлагатай гэдэг нь амьдрал дээрх үйл хэрэг, үйлдэл бүрээс чинь харагддаг, учир нь та нар хэтэрхий дутуу дулимаг агаад та нарын мэдлэг болон ойлгох чадвар

хэтэрхий хомс билээ. Өдөр тутмын амьдралдаа та нар үнэн эсвэл эрүүл саруул ухаан гэж байхгүй орчин, нөхцөлд дунд амьдардаг. Та нарт амь зуух чадвар дутдаг ба Намайг эсвэл үнэнийг мэдэх суурь байдаггүй. Та нарын итгэл ердөө л тодорхойгүй, хийсвэр итгэл үнэмшил дээр эсвэл хэт онолын мэдлэг болон шашны зан үйл дээр суурилсан байдаг. Өдөр бүр Би та нарын үйл хөдлөлийг ажиглаж, санаа зорилго, ёрын муу үр жимсийг чинь шинжилж байдаг бөгөөд хэзээ ч хөдөлгөөгүй Миний тахилын ширээн дээр зүрх сэтгэл болон сүнсээ үнэхээр тавьсан нэгнийг Би ер олоогүй. Иймд Би илэрхийлэхийг хүссэн бүх үгээ ийм хүн төрөлхтөнд тоочиж цагаа үрэхийг хүсэхгүй байна. Би зүрх сэтгэлдээ зөвхөн дуусгаагүй ажлаа дуусгаж, хүн төрөлхтөн дундаас Өөрийн хараахан авраагүй хүмүүсийг аврахаар төлөвлөж байна. Гэсэн хэдий ч, Намайг дагадаг бүхэн Миний авралыг болон Миний үгийн хүнд хайрладаг үнэнийг хүлээн аваасай гэж Би хүсдэг. Нэг л өдөр нүдээ аних үедээ чи тэнгэр нь хар үүлэнд хиртсэн, орь дуу хэзээ ч тасардаггүй баргар хүйтэн ертөнцийг бус, харин агаар нь анхилуун үнэрээр дүүрсэн, амийн усны булаг урссан ертөнцийг харна гэж Би найддаг.

Өдөр бүр хүн болгоны үйл хэрэг болон бодлыг тэрхүү Нэгэний нүд харж ажиглаж байдаг, үүний зэрэгцээ тэдний маргаашийн төлөө бэлдэж байдаг. Энэ бол бүх амьд буй хүний алхах ёстой зам; энэ бол бүгдэд зориулж Миний урьдчилан тогтоосон зам бөгөөд хэн ч үүнээс зугтаж чадахгүй, бас хэнийг ч үүнээс ангид болгохгүй. Миний хэлсэн үг тоо томшгүй олон, цаашлаад Миний хийсэн ажил хэмжээлшгүй их. Хүн болгон хийх ёстой зүйлээ төрөлх уг чанар ба уг чанарынхаа хөгжлийн дагуу жам ёсоороо хэрэгжүүлж байгааг Би өдөр бүр ажигладаг. Олон хүн өөрийн мэдэлгүйгээр аль хэдийн “зөв замд” орсон бөгөөд энэ зөв замыг Би төрөл бүрийн хүнийг илчлэхийн тулд барьсан юм. Эдгээр төрөл бүрийн хүнийг Би аль хэдийн өөр өөр орчинд байрлуулсан бөгөөд тэд дор бүрнээ байгаа газраа төрөлх шинж чанараа илэрхийлсэн. Тэднийг хүлж баглах хэн ч байхгүй, тэднийг уруу татах хэн ч байхгүй. Тэд бүрэн эрх чөлөөтэй байдаг бөгөөд тэдний илэрхийлдэг зүйл аяндаа гарч ирдэг. Тэднийг хянадаг цорын ганц зүйл байдаг нь Миний үг юм. Иймээс зарим хүн үхлээс зайлсхийх гэсэндээ л Миний үгийг дуртай дургүй уншдаг боловч хэзээ ч хэрэгжүүлдэггүй; гэтэл зарим хүний хувьд өөрсдийг нь хангаж, залж чиглүүлэх Миний үг байхгүй бол өдөр хоногийг өнгөрөөх хэцүү байдаг, иймээс тэд угаасаа л Миний үгийг цаг үргэлж зуурч байдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд хүний амьдралын нууц, хүн төрөлхтний хүрэх газар болон хүн байхын үнэ цэнийг олж нээдэг. Миний үгийн өмнө хүн төрөлхтний байгаа байдал ердөө л энэ бөгөөд Би хэрэг явдал бүхнийг зүгээр л жам ёсоор нь явуулдаг. Би үгийг минь оршин тогтнолынхоо үндэс болго гэж хүнийг албадсан ямар ч зүйл хийдэггүй. Иймд, хэзээ ч мөс чанартай байгаагүй, хэзээ ч үнэ цэнтэй оршин тогтнож байгаагүй хүмүүс аливаа зүйл хэрхэн өрнөхийг чимээгүйхэн ажиглаж байгаад дараа нь Миний үгийг зоримгоор хаяж, өөрсдийнхөө дураар аашилдаг. Тэд үнэнийг болон Надаас ирдэг бүхнийг жигшиж эхэлдэг. Түүнчлэн, Миний гэрт байхыг жигшдэг. Энэ хүмүүс үйлчлэл

хийж байсан ч гэсэн хүрэх газрынхаа төлөө, мөн шийтгэлээс мултрахын тулд л Миний гэрт түр амьдардаг. Гэвч тэдний санаа зорилго, үйлдэл хэзээ ч өөрчлөгддөггүй. Энэ нь тэдний ерөөл хүсэх хүслийг, мөн хаанчлалд нэг орongуутаа тэндээ үүрд үлдэж, бүр мөнхийн диваажинд орох хүслийг нь бадраадаг. Миний өдрийг аль болох хурдан ирээсэй гэж хүсэх тусмаа тэд үнэнийг замд нь улам их саад, тээг болж байгааг мэдэрдэг. Тэд үнэнийг эрэлхийлэх юм уу шүүлт, гэсгээлтийг хүлээн авалгүйгээр, хамгийн гол нь Миний гэрт бөхөлзөж, Миний тушааснаар хийх шаардлагагүйгээр тэнгэрийн хаанчлалын ерөөлийг үүрд эдлэхээр хаанчлалд хөл тавихаа тэсэн ядан хүлээж байдаг. Энэ хүмүүс Миний гэрт үнэнийг эрж хайх хүслээ хангах гэж ч ордоггүй, Миний удирдлагатай хамтран ажиллах гэж ч ордоггүй. Тэд зүгээр л ирж буй эрин үед устгагдахгүй байх хүмүүсийн нэг байхыг зорьдог. Иймээс тэдний зүрх сэтгэл үнэн гэж юу болох, үнэнийг яаж хүлээн зөвшөөрөхийг хэзээ ч мэдэж байгаагүй. Энэ хүмүүс үнэнийг хэрэгжүүлж үзээгүй, эсвэл ямар гүн ялзарсан гэдгээ ухамсарлаж байгаагүй мөртөө Миний гэрт “үйлчлэгч”-ийн дүрээр энэ бүх хугацаанд амьдарч байсны шалтгаан энэ юм. Тэд Миний өдөр ирэхийг “тэвчээртэйгээр” хүлээж, Миний ажлын хэв маягийн дагуу ийш тийш шидэгдэж байсан ч цуцдаггүй. Гэвч тэд хэчнээн их хүчин чармайлт гаргаж, ямар ч төлөөс төлсөн байсан хамаагүй, тэднийг үнэний төлөө зовж, Миний төлөө ямар нэгэн юм зориулж байсныг нь хэн ч хэзээ ч харж байгаагүй. Хуучин эрин үеийг төгсгөл болгох өдрийг минь тэд зүрх сэтгэлдээ хүлээж яддаг, түүнчлэн тэд Миний хүч чадал, эрх мэдэл хэр агуу болохыг мэдэхийг асар их хүсдэг. Тэдний хийх гэж хэзээ ч яарч байгаагүй зүйл бол өөрсдийгөө өөрчилж, үнэнийг эрэлхийлэх явдал юм. Тэд Миний залхдаг зүйлийг хайрлаж, Миний хайрладаг зүйлээс залхдаг. Тэд Миний үзэн яддаг зүйлийг хүсэмжилдэг ч Миний зэвүүцдэг зүйлийг алдахаас айдаг. Тэд энэхүү хорон муу ертөнцөд амьдарч, үүнийгээ хэзээ ч жишдэггүй мөртөө Намайг энэ ертөнцийг устгах вий гэхээс маш их айдаг. Санаа зорилгын зөрчилдөөн дотроо тэд Миний жигшин зэвүүцдэг энэ ертөнцийг хайрладаг атлаа Намайг нэн даруй энэ ертөнцийг устгаасай гэж хүсэн хүлээдэг. Тэгснээр тэд үнэн замаас хазайхаасаа өмнө сүйрлийн зовлонгоос хэлтэрч, дараагийн эрин үеийн эзэд болон хувирах юм байх. Учир нь тэд үнэнийг хайрладаггүй агаад Надаас ирдэг бүхнээс залхсан байдаг. Тэд ерөөлийг алдахгүйн тулд хэсэг зуур “дуулгавартай хүмүүс” болж магадгүй боловч, тэдний ерөөлд шунадаг сэтгэхүй болон шатаж байгаа галт нуурт орж, мөхөхөөс айх айдас хэзээ ч балрахгүй. Миний өдөр ойртох тусам тэдний хүсэл аажмаар эрчээ авсаар байдаг. Гамшиг их байх тусам тэд Намайг баярлуулж, удаан хүсэн хүлээсэн ерөөлөө алдчихгүй байхын тулд хаанаас эхлэхээ мэдэхгүй улам арга мухарддаг. Миний гар ажлаа хийж эхэлмэгц энэ хүмүүс тэргүүн эгнээнд үйлчлэх гэж хүслэн болдог. Тэд Миний нүдэнд өртөхгүй байх вий гэж маш их айн, жагсаалын тэргүүн эгнээнд очих тухай л боддог. Тэд өөрсдийнх нь үйл хэрэг болон үйлдэл хэзээ ч үнэнтэй хамаагүй байсан гэдгийг огт мэдэлгүйгээр өөрсдийнхөө зөв гэж боддог зүйлийг хэлж, хийдэг бөгөөд тэдний үйл хэрэг ердөө л Миний

төлөвлөгөөг үймүүлж, саад болж байдаг. Тэд асар их хүчин чармайлт гаргасан, хүнд бэрхийг туулах шийдэмгий зан болон санаа зорилго нь үнэн байж болох ч тэдний хийдэг бүхэн Надтай ямар ч хамаагүй, учир нь тэдний үйлдэл сайн санааны үүднээс гарч байхыг Би хэзээ ч хараагүй, тэр ч байтугай Миний тахилын ширээн дээр ямар нэг юм тавихыг нь Би хараагүй. Энэ олон жилийн турш Миний өмнө тэдний хийсэн үйл хэрэг энэ билээ.

Эхэндээ Би та нарыг илүү их үнэнээр хангахыг хүссэн боловч үнэнд хандах та нарын хандлага хэтэрхий цэвдэг, хайхрамжгүй байсан тул болих хэрэгтэй болсон; Би хүчин чармайлтаа дэмий үрэхийг хүсдэггүй, мөн хүмүүс үгийг минь зуурах атлаа бүх талаар Намайг эсэргүүцэж, гүтгэж, доромжлох зүйл хийж байгааг харахыг ч хүсдэггүй. Хандлага, хүн чанараас чинь болж Би, та нарын хувьд маш чухал үгийнхээ багахан хэсгээр та нарыг хангадаг бөгөөд энэ нь хүн төрөлхтний дундах Миний туршилтын ажил болдог юм. Одоо л Би гаргасан шийдвэр, төлөвлөгөө минь та нарын хэрэгцээнд нийцсэн байгааг үнэхээр баталгаажуулж, цаашлаад хүн төрөлхтөнд хандах Миний хандлага зөв болохыг баталлаа. Миний өмнө гаргасан та нарын олон жилийн зан авир, урьд нь Миний хэзээ ч хүлээн авч байгаагүй хариултыг Надад өгсөн. Уг хариултын асуулт нь энэ: “Хүн үнэний болоод жинхэнэ Бурханы өмнө ямар хандлагатай байдаг вэ?” Хүнд зориулсан Миний хүчин чармайлт хүнийг хайрлах мөн чанарыг минь баталдаг бөгөөд хүний Миний өмнө хийсэн үйлдэл бүхэн үнэнийг үзэн ядаж, Надтай дайсагнадаг мөн чанарыг нь баталдаг. Намайг дагадаг бүхэнд Би цаг үргэлж санаа тавьдаг боловч Намайг дагадаг хүмүүс хэзээд Миний үгийг хүлээн авах чадваргүй байдаг; тэд бүр Миний өгсөн зөвлөгөөг ч хүлээн авч чаддаггүй. Юу юунаас илүүтэй энэ л Намайг гуниглуулдаг. Миний хандлага чин сэтгэлийнх агаад Миний үг зөөлөн боловч хэн ч, хэзээ ч Намайг ойлгож чадаагүй, түүнчлэн хэн ч Намайг хүлээн авч чадаагүй. Миний даалгасан ажлыг хүн бүр санаандаа нийцүүлэн хийхээр хичээдэг; тэд Миний санаа зорилгыг эрж хайх нь байтугай өөрсдөөс нь юу шаардаж байгааг минь ч асуудаггүй. Тэд байнга л Миний эсрэг тэрсэлдэг хэр нь Надад үнэнчээр үйлчилдэг гэж хэлсээр байдаг. Өөрсдийнх нь хувьд хүлээн авах аргагүй, хэрэгжүүлж чадахгүй үнэн бол үнэн биш гэж олон хүн боддог. Ийм хүмүүсийн хувьд Миний үнэн үгүйсгэгдэж, хаягдах зүйл болдог. Үүний зэрэгцээ хүмүүс Намайг аман дээрээ Бурхан гэж хүлээн зөвшөөрдөг ч үнэн, зам, амь биш, харин гаднын хүн гэж бас боддог. Хэн ч энэ үнэнийг мэддэггүй: Миний үг бол үүрд үл өөрчлөгдөх үнэн юм. Би бол хүний амийн тэжээл бөгөөд хүн төрөлхтний цорын ганц хөтөч билээ. Миний үгийн үнэ цэн болон утга учир нь хүн төрөлхтөнд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн эсэхээр бус, харин үгийн өөрийнх нь мөн чанараар тодорхойлогддог. Энэ газар дэлхий дээр Миний үгийг ганц ч хүн хүлээн авахгүй байлаа ч гэсэн Миний үгийн үнэ цэн болон хүн төрөлхтөнд өгөх тусламжийг ямар ч хүн хэмжихийн аргагүй. Иймд Миний үгэнд тэрсэлж, үгийг минь няцаах юм уу, анзаардаггүй олон хүнтэй учрах үедээ Би ийм л хандлагатай байдаг: Цаг хугацаа болон баримтууд Миний гэрч

болж, Миний үг бол үнэн, зам, амь юм гэдгийг харуулаг. Миний хэлсэн бүхэн зөв болохыг, энэ нь хүний эзэмших ёстой зүйл гэдгийг, мөн түүнчлэн энэ нь хүний хүлээн авах ёстой зүйл гэдгийг тэдэнд харуулаг. Намайг дагадаг бүх хүнд Би дараах баримтыг мэдэгдэх болно: Миний үгийг бүрэн хүлээн авч чаддаггүй хүмүүс, Миний үгийг хэрэгжүүлж чаддаггүй хүмүүс, Миний үгээс зорилго олж чаддаггүй хүмүүс, Миний үгийн ачаар аврал хүлээн авч чаддаггүй хүмүүс бол Миний үгээр яллагдсан, түүнчлэн Миний авралыг алдсан хүмүүс бөгөөд Миний саваа хэзээ ч тэднээс холдохгүй.

2003 оны 4 дүгээр сарын 16

БУРХАН БОЛ ХҮНИЙ АМИЙН ЭХ СУРВАЛЖ

Чи энэ ертөнцөд дуугаа хадаан мэндэлсэн тэр мөчөөс өөрийн үүргийг биелүүлж эхэлдэг. Бурханы төлөвлөгөө болон Түүний томилгооны төлөө чи үүрэг ролио биелүүлж, амьдралын аянаа эхэлдэг. Чиний яаж өсөж торнисон, урд чинь чамайг ямар аян хүлээж байгаа нь хамаагүй, Тэнгэрийн зохион байгуулалт, зохицуулалтаас хэн ч зайлж чадахгүй бөгөөд хэн ч өөрийн хувь заяаг хянаж чаддаггүй, учир нь бүх зүйлийг захирдаг Тэр л ийм зүйл хийх чадвартай. Хүн төрөлхтөн бий болсон цагаас эхлэн Бурхан хэзээд ийнхүү ажиллаж, орчлон ертөнцийг удирдан, бүх зүйлийн өөрчлөлтийн хуулийг болон шилжилт хөдөлгөөнийг нь чиглүүлж ирсэн билээ. Бүх зүйлийн адилаар хүн Бурханы чихэрлэг амт, бороо, шүүдрээр чимээгүйхэн, өөрийн мэдэлгүй тэжээгддэг; бүх зүйлийн адилаар хүн өөрийн мэдэлгүйгээр Бурханы гарын зохион байгуулалт дор амьдардаг. Хүний зүрх сэтгэл болон сүнс Бурханы гарт байдаг ба амьдралынх нь бүх зүйлийг Бурханы нүд хардаг. Үүнд итгэх үгүй чинь хамаагүй, амьд ч бай, үхсэн ч бай аливаа бүх зүйл Бурханы бодлын дагуу хувирч, өөрчлөгдөж, шинэчлэгдэн, алга болдог. Энэ бол Бурханы бүх зүйлийг удирддаг арга зам юм.

Шөнийн харанхуй сэмхэн ойртож байхад хүн мэддэггүй, учир нь шөнө хэрхэн нөмөрдгийг ч тэр, хаанаас ирдгийг ч тэр хүний зүрх сэтгэл ухамсарлаж чаддаггүй юм. Шөнө сэмхэн дайжин одоход хүн өдрийн гэрлийг угтан авдаг боловч гэрэл хаанаас ирснийг, шөнийн харанхуйг хэрхэн хөөснийг мэддэг ч үгүй, мэдэрдэг ч үгүй. Ээлжлэн солигдох өдөр, шөнө хүнийг нэг үеэс нөгөөд, түүхийн нэг нөхцөлөөс нөгөөд аваачихын хажуугаар цаг үе болгон дахь Бурханы ажил болон эрин үе бүрд зориулсан Түүний төлөвлөгөөг гүйцэлдүүлж ирсэн. Хүн эдгээр цаг үеийн турш Бурхантай хамт алхаж ирсэн атлаа Бурхан бүх зүйл болон амьд бодгалийн хувь заяаг захирдгийг, мөн Бурхан бүх зүйлийг хэрхэн зохион байгуулж, чиглүүлдгийг мэддэггүй. Балар эртний цаг үеэс өнөөдрийг хүртэл хүн үүнийг ухаараагүй явжээ. Үүний шалтгаан нь, Бурханы үйл хэрэг хэтэрхий нуугдмал байдагт бус, Бурханы

төлөвлөгөө биелэх болоогүйдээ ч бус, харин хүний зүрх сэтгэл болон сүнс Бурханаас хэтэрхий хол байдаг учраас, тиймдээ ч хэдий Бурханыг дагаж байсан ч сатанд үйлчилсээр л байдаг бөгөөд үүнийгээ ч хүртэл мэддэггүйд оршиж байгаа юм. Бурханы мөр болон илрэлтийг хэн ч идэвхийлэн эрж хайдаггүй бөгөөд Бурханы халамж, хамгаалалт дор оршихыг хэн ч хүсдэггүй. Харин оронд нь тэд энэ хорвоо, хорон муу хүн төрөлхтний дагадаг оршин тогтнолын дүрэмд дасан зохицохын тулд ёрын муу нэгэн болох сатаны муу нөлөөнд түшиглэхийг хүсдэг. Энэ цаг үед хүн зүрх сэтгэл, сүнсээ Сатанд барих өргөл, Сатаны идэш тэжээл болгосон. Тэр ч бүү хэл хүний зүрх сэтгэл, сүнс нь Сатаны орогнож болох газар, зугаацахад тохиромжтой талбар болсон билээ. Тиймээс, хүн байх зарчим, хүний оршин тогтнолын үнэ цэн, утга учрын талаарх ойлголтоо хүн өөрөө ч мэдэлгүй гээдэг. Бурханы хууль, Бурхан, хүн хоёрын гэрээ хүний зүрх сэтгэлд аажмаар бүдгэрч, хүн Бурханыг эрж хайн, Бурханд анхаарал хандуулахаа больдог. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүн Бурхан яагаад өөрийг нь бүтээснийг, түүнчлэн Бурханы амнаас гарч байгаа үг болон Бурханаас гаралтай бүхнийг ч бас ойлгохоо больдог. Дараа нь хүн Бурханы хууль, зарлигийг эсэргүүцэж эхэлдэг ба зүрх сэтгэл, сүнс нь мэдээгүй болдог… Бурхан анх бүтээсэн хүнээ алдаж, хүн анх өөрт нь байсан үндсийг алддаг: Энэ бол энэ хүн төрөлхтний уй гашуу билээ. Чухамдаа гэвэл, бүр эхнээсээ өнөөг хүртэл Бурхан хүн төрөлхтөнд зориулан эмгэнэлт жүжиг тайзнаа тавьсан бөгөөд хүн үүний гол дүр төдийгүй хохирогч нь юм. Тэгээд энэхүү эмгэнэлт жүжгийн найруулагч нь хэн болохыг хэн ч хариулж чаддаггүй.

Ертөнцийн өргөн уудам чөлөөнд ахин дахин, далай тэнгис лаг шаварт идэгдэн хээр тал болж, хээр тал үерлэн далай тэнгис болж хувирсаар байна. Бүх зүйлийн дундах бүхнийг захирдаг Нэгнээс өөр хэн ч энэ хүн төрөлхтнийг удирдаж, замчилж чадахгүй. Энэхүү хүн төрөлхтний төлөө хөдөлмөрлөж, бэлтгэл базаах хүчирхэг нэгэн үгүй бөгөөд энэхүү хүн төрөлхтнийг гэрэл гэгээтэй хүрэх газар луу хөтөлж, хүний ертөнцийн шударга бус байдлаас чөлөөлж чадах нэгэн бүр ч байхгүй. Бурхан хүн төрөлхтний ирээдүйд халаглаж, хүн төрөлхтний уналтад гашуудан, хүн төрөлхтөн доройтол руу, эргэж ирэхээргүй зам руу алхам алхмаар урагшилж байгаад шаналдаг. Бурханы зүрх сэтгэлийг эмтрүүлж, Түүнийг хөсөр хаяад ёрын муу нэгнийг эрж хайж буй энэ хүн төрөлхтөн аль чиглэлд явж буйг хэн ч, хэзээ ч бодож үзээгүй. Ийм учраас л Бурханы уур хилэнг хэн ч мэдэрдэггүй, Бурханы таалалд нийцэх замыг хэн ч эрж хайдаггүй, Бурхантай ойртох гэж хэн ч хичээдэггүй, түүнчлэн Бурханы уй гашуу, шаналлыг ойлгох гэж хэн ч эрж хайдаггүй. Бурханы дуу хоолойг сонссоныхоо дараа ч гэсэн хүн өөрийнхөө замаар үргэлжлүүлэн явж, Бурханаас холдон, Бурханы нигүүлсэл, халамжаас зайлсхийж, Түүний үнэнээс зайлж, Бурханы дайсан болох Сатанд өөрийгөө худалдахыг илүүд үздэг. Хүн зөрүүдэлсэн хэвээр байвал Өөрийг нь эргэж ч харалгүй орхисон энэ хүн төрөлхтөнд Бурхан хэрхэн хандах тухай хэн бодож үзсэн бэ? Хүний махан бие, сүнс тэсвэрлэшгүй, урьд хожид үзэгдээгүй гай гамшгийг Бурхан гартаа бэлтгээд байгаа

учраас л хүн төрөлхтөнд дахин давтан анхааруулж, сануулаад байгааг хэн ч мэддэггүй. Энэхүү гай гамшиг нь дан ганц хүний махан биеийн бус, бас сүнсний шийтгэл байдаг. Чи үүнийг мэдэх хэрэгтэй: Бурханы төлөвлөгөө бүтэлгүйтэж, Түүний анхааруулга, сануулгад хариулахгүй байх үед Бурхан яаж уурсаж, хилэгнэх бол? Энэ нь ямар ч бүтээгдсэн зүйлийн урьд нь мэдэрч, сонсож байсантай адилгүй байх болно. Иймээс энэхүү гай гамшиг нь урьд үзэгдээгүй бөгөөд хэзээ ч давтагдахгүй гэж Би хэлнэ. Учир нь хүн төрөлхтнийг ганц л удаа бүтээж, мөн хүн төрөлхтнийг ганц л удаа аврах нь Бурханы төлөвлөгөө билээ. Энэ бол эхнийх төдийгүй эцсийнх юм. Тиймээс энэ удаад хүн төрөлхтнийг аварч байгаа Бурханы уйгагүй сэтгэл, яарсан хүлээлтийг хэн ч ойлгож чадахгүй.

Бурхан энэ дэлхийг бүтээж, Өөрийн амь хайрласан амьд бодгаль болох хүнийг дэлхийд авчирсан. Дараа нь хүн эцэг эх, төрөл төрөгсөдтэй болж, ганцаар байхаа больсон юм. Хүн энэхүү материаллаг ертөнцийг анх харснаасаа хойш Бурханы тогтоосноор оршин байх заяатай байв. Бурханаас гарсан амийн амьсгал л амьд оршихуй болгоныг өсөж, нас бие гүйцэх хүртэл нь тэтгэдэг билээ. Энэ явцад, хүн Бурханы халамж дор өсөж байна гэдгийг хэн ч мэдэрдэггүй, харин эцэг эхийнхээ хайр халамж дор өсөж байгаа бахүний амийн зөн совин өсөх үйл явцыг нь чиглүүлдэг хэмээн боддог. Учир нь өөрийнх нь амийг хэн хайрлаж, амь нь хаанаас ирснийг хүн мэддэггүй бөгөөдамийн зөн совин хэрхэн гайхамшгийг бүтээдгийг бүр ч мэддэггүй. Хоол хүнс бол амь амьдралынх нь үргэлжлэлийн үндэс, шийдэмгий байдал бол оршин тогтнолынх нь эх сурвалж бөгөөд оюун санаан дахь итгэл нь амь зуулгынх нь үнэт хөрөнгө гэдгийг л хүн мэддэг. Бурханы нигүүлсэл, хангалтыг хүн огт анзаардаггүй, энэ маягаар өөрт нь Бурханы хайрласан амийг дэмий үрдэг… Бурханы өдөр, шөнөгүй халамжилдаг энэхүү хүмүүсээс ганц нь ч Түүнийг шүтэн мөргөх санаачилга гаргадаггүй. Бурхан төлөвлөсөн ёсоороо, ямар ч найдлагагүй хүн дээр үргэлжлүүлэн ажилласаар л байдаг. Нэг л өдөр хүн зүүднээсээ сэрээд амийн үнэ цэн, утга учир, мөн хүнд өгсөн бүхнийхээ төлөө Бурханы төлсөн төлөөс, хүнийг Өөр лүү нь эргээсэй хэмээн хүлээдэг Бурханы яарсан сэтгэлийг гэнэт ухаарна хэмээн Тэр найддаг. Хүний амийн үүсэл ба үргэлжлэлийн нууцуудыг хэн ч, хэзээ ч судалж үзээгүй. Энэ бүхнийг ойлгодог Бурхан л, Өөрөөс нь бүх зүйлийг хүлээн авсан мөртөө талархдаггүй хүний учруулдаг шаналал, цохилтыг чимээгүйхэн тэвчдэг. Амийн авчирдаг бүхнийг хүн жам ёсны зүйл шиг эдэлдэг ба тийм ч болохоор Бурханаас урваж, Бурханыг мартан, Бурханаас сүрдүүлэн авдаг нь “мэдээжийн хэрэг” билээ. Бурханы төлөвлөгөө үнэхээр тийм чухал юм гэж үү? Хүн гэдэг, Бурханы гараас гарсан энэхүү амьд бодгаль үнэхээр тийм чухал юм гэж үү? Бурханы төлөвлөгөө мэдээж чухал; гэвч Бурханы гараар бүтээгдсэн энэхүү амьд бодгаль Түүний төлөвлөгөөний төлөө оршин тогтнодог. Иймд Бурхан энэ хүн төрөлхтнийг үзэн ядсандаа төлөвлөгөөгөө гаргуунд нь гаргачхаж чадахгүй. Бурхан Өөрийн төлөвлөгөө болон Өөрийн гаргасан амьсгалын төлөө, хүний махан бие бус, хүний амийн төлөө л бүх зовлон шаналлыг тэвчдэг билээ. Тэрээр хүний махан

биеийг бус, амьсгалсан амиа буцааж авахын тулд л ингэдэг юм. Энэ бол Түүний төлөвлөгөө юм.

Энэ дэлхийд ирсэн хүн бүхэн амьдрал, үхлийг туулах ёстой бөгөөд тэдний ихэнх нь үхэл, дахин төрөлтийн мөчлөгөөр дамжин өнгөрсөн. Амьдарч байгаа нь удахгүй үхэж, үхсэн нь удахгүй эргэн ирнэ. Энэ бүхэн нь амьд бодгаль болгонд зориулан Бурханы зохицуулсан амийн замнал билээ. Гэвч энэхүү замнал, энэ мөчлөг бол Бурханы хүнд яг харуулахыг хүссэн үнэн юм: Бурханы хүнд хайрласан амь хязгааргүй бөгөөд махан бие, цаг хугацаа, орон зайд баригддаггүй. Энэ бол Бурханы хүнд хайрласан амийн нууц бөгөөд амь Түүнээс ирсэн гэдгийн нотолгоо билээ. Хүний амь Бурханаас ирсэн гэдэгт олон хүн итгэдэггүй байж болох ч Түүний оршин тогтнолд итгэдэг ч бай, үгүйсгэдэг ч бай ялгаагүй, Бурханаас ирдэг бүхнийг хүн зайлшгүй эдэлдэг. Хэрвээ нэг өдөр Бурхан гэнэт бодлоо өөрчилж, дэлхий дээр оршдог бүхнийг эргүүлэн авахыг хүсэж, өгсөн амиа буцаан авбал бүх зүйл үгүй болно. Бурхан өөрийн амиар амьтай, амьгүй бүх зүйлийг хангаж; Өөрийн агуу хүч, эрх мэдлээр бүхнийг дэг журамтай байлгадаг. Энэ бол хэний ч төсөөлж, ойлгож чадахгүй үнэн бөгөөд эдгээр ойлгох аргагүй үнэн бол Бурханы амийн хүчний яг жинхэнэ илрэл, гэрчлэл билээ. Одоо Би чамд нэг нууц хэлье: Бурханы амийн агуу байдал болон Түүний амийн хүч чадлыг ямар ч бүтээл ойлгох аргагүй. Одоо ийм байгаа, урьд нь ийм байсан, мөн хожим ч тийм байх болно. Миний хуваалцах хоёр дахь нууц бол энэ: Бүх бүтээгдсэн зүйлийн хувьд амийн хэлбэр, бүтцээрээ хэчнээн өөр байсан ч хамаагүй, амийн эх сурвалж нь Бурханаас ирдэг; чи ямар ч төрлийн амьд бодгаль байсан ялгаагүй Бурханы тогтоосон амийн замыг зөрчиж чадахгүй. Ямартай ч хүн үүнийг ойлгоосой гэж л Би хүсдэг: Бурханы халамж, хамгаалалт, хангалтгүйгээр хүн хэчнээн шаргуу зүтгэж, хэчнээн хүч гарган тэмцлээ ч гэсэн хүлээн авах учиртай бүхнээ хүлээн авч чадахгүй. Бурханы амийн хангалтгүйгээр хүн амьдрахын үнэ цэн, амийн утга учрыг алддаг. Амийнх нь үнэ цэнийг дэмий үрдэг хүний ийм санаа амар байдлыг Бурхан яаж зөвшөөрч чадах юм бэ? Өмнө нь Миний хэлсэнчлэн, Бурхан бол чиний амийн эх сурвалж гэдгийг бүү март. Хэрвээ хүн Бурханы хайрласан бүхнийг нандигнаж чадахгүй бол Бурхан анх өгсөн зүйлээ эргүүлэн аваад зогсохгүй, Өөрийнхөө өгсөн бүхний үнийг хүнээр хоёр нугалан төлүүлнэ.

2003 оны 5 дугаар сарын 26

ТӨГС ХҮЧИТИЙН САНАА АЛДАЛТ

Чи гэрэлгүй ертөнцөд амьдарсаар ирсэн тул чиний зүрх сэтгэлд асар том нууц байгааг хэзээ ч анзаарч байгаагүй. Зүрх сэтгэл, сүнсийг чинь муу ёрын нэгэн булаан авчихсан. Нүд чинь харанхуйд халхлагдаад тэнгэрийн нарыг ч, шөнийн

огторгуйд анивчих тэр одыг ч харж чаддаггүй. Чих чинь худал хуурмаг үгээр дүүрээд Еховагийн нүргэлсэн дуу хоолойг ч, сэнтийгээс урсах их усны чимээг ч сонсдоггүй. Өөрт байх ёстой бүхнээ, Төгс Хүчитийн хайрласан бүхнийг чи алдчихсан. Чи өөрийгөө аврах хүч чадалгүй, амьд гарах найдлагагүйгээр эцэс төгсгөлгүй зовлонгийн далайд орчхоод тэмцэж, сандрахаас өөрийг хийдэггүй… Тэр мөчөөс эхлээд чи ёрын муу нэгэнд хорлогдож, Төгс Хүчитийн ерөөлөөс холдож, Төгс Хүчитийн хангалтаас салж, эргэж буцалтгүй замаар алхах тавилантай болсон. Сая дуудлага ч зүрх сэтгэл, сүнсийг чинь сэрээж бараг чадахгүй. Чамайг зүг чиггүй, замын тэмдэггүй эх захгүй ертөнцөд уруу татаж оруулсан ёрын муу нэгний гарт чи дугжирдаг. Энэ үеэс хойш чи анхдагч гэм зэмгүй, цэвэр байдлаа алдаж, Төгс Хүчитийн халамжаас зайлсхийж эхэлсэн. Ёрын муу нэгэн чиний зүрх сэтгэлд бүх хэрэг явдлыг залж чиглүүлэн, чиний амь болсон. Чи түүнээс айж, зайлсхийж, түүнд эргэлзэхээ больсон; харин ч зүрх сэтгэлдээ түүнийг Бурхан мэт үздэг. Чи түүнийг тахиж, шүтэж эхэлсэн бөгөөд та хоёр бие, сүүдэр хоёр шиг салшгүй болж, хамт амьдарч, үхнэ гэж амлажээ. Чи хаанаас ирсэн, яагаад төрсөн, яагаад үхэхээ огт мэддэггүй. Чи Төгс Хүчитийг танихгүй нэгэн мэтээр хардаг; чи Түүний гарал үүслийг мэддэггүй, чиний төлөө хийсэн бүхнийг нь бүр ч мэддэггүй. Түүнээс ирдэг бүхэнд чи хорсох болсон; үүнийг нь нандигнадаггүй, үнэ цэнийг нь ч мэддэггүй. Төгс Хүчитийн хангалтыг хүлээн авсан өдрөөсөө эхлээд чи муу ёрын нэгний хажууд алхдаг. Чи муу ёрын нэгний хамтаар олон мянган жил ширүүн бороо, догшин шуургыг туулсан бөгөөд амийн чинь эх сурвалж байсан Бурханы эсрэг түүнтэй хамт зогсдог. Чи гэмшлийн талаар юу ч мэддэггүй, мөхлийн ирмэгт ирсэн гэдгээ бүр ч мэддэггүй. Муу ёрын нэгэн чамайг уруу татаж, зовоосон гэдгийг чи мартчихаж; эхэн үеэ чи мартчихжээ. Муу ёрын нэгэн өнөөдрийг хүртэл чамайг ингэж алхам алхмаар зовоожээ. Зүрх сэтгэл, сүнс чинь мэдээ алдаж, доройтсон. Чи хүний ертөнцийн гаслан зовлонгийн талаар гомдоллохоо больсон; дэлхий ертөнц бол шударга бус гэж бодохоо ч больсон. Төгс Хүчит оршин байдаг эсэхийг бүр ч тоодоггүй. Яагаад гэвэл, чи муу ёрын нэгнийг аль хэдийн жинхэнэ эцгээ гэж үзчихээд түүнээс хагацаж чаддаггүй. Энэ бол зүрх сэтгэлийн чинь доторх нууц юм.

Үүр цайхад үүрийн цолмон зүүн зүгт гялалзаж эхэлдэг. Энэ бол урьд нь хэзээ ч байгаагүй од бөгөөд тайван амгалан, сүүмэлзсэн тэнгэрийг гэрэлтүүлж, хүмүүсийн зүрх сэтгэл дэх бөхсөн гэрлийг дахин асаадаг. Энэхүү гэрлийн ачаар хүмүүс ганцаардахаа больж, энэ нь чам дээр ч, бусад дээр ч адилхан тусдаг. Гэсэн ч чи ганцаараа харанхуй шөнө бөх унтсаар үлддэг. Чи ямар ч чимээ сонсдоггүй, ямар ч гэрэл хардаггүй; шинэ тэнгэр газар, шинэ эрин үе ирснийг мэддэггүй, учир нь эцэг чинь чамд “Үр минь, битгий бос, бас л эрт байна. Цаг агаар хүйтэн байгаа болохоор гадаа бүү гар, илд, жад нүдийг чинь сүлбэх вий” гэж хэлдэг. Чи эцгийнхээ сануулгад л итгэдэг, учир нь эцэг чинь чамаас ахмад, мөн чамайг ихэд хайрладаг болохоор чи гагцхүү эцгийн чинь зөв гэдэгт итгэдэг. Ийм сануулга, ийм хайр нь дэлхий ертөнцөд гэрэл байдаг хэмээх домогт итгэхийг чинь болиулдаг; энэ дэлхийд үнэн

оршсоор байдаг эсэхийг хайхрахгүй болгодог. Чи Төгс Хүчитээр авруулна гэж горьдож зүрхлэхээ больдог. Чи байгаа байдалдаа сэтгэл ханаж, гэрэл гарч ирэхийг хүлээхээ больж, домогт өгүүлсэнчлэн Төгс Хүчитийн залран ирэхийг харуулдан хүлээхээ больдог. Чиний хувьд гэвэл, үзэсгэлэнтэй сайхан бүхэн дахин сэргэж, оршин тогтнох боломжгүй. Чиний нүдээр бол хүн төрөлхтний маргааш, хүн төрөлхтний ирээдүй зүгээр л үгүй болж, ор мөргүй арилдаг. Чи эцгийнхээ хувцаснаас бүх чадлаараа зуурч, бэрхшээл зовлонг нь хуваалцахад бэлэн байж, замын ханиа болон алсын аяныхаа зүг чигийг алдахаас ихэд айдаг. Өргөн уудам агаад будант хүний ертөнц энэ дэлхийн өөр өөр үүргийг туйлбартай, аймшиггүйгээр биелүүлдэг та нарыг олноор бий болгожээ. Үхлээс огт айдаггүй олон “дайчныг” бүтээжээ. Түүнээс гадна, энэ нь бүтээлийнхээ зорилгыг мэддэггүй, мэдээ алдаж, саажсан хүмүүсийг бөөн бөөнөөр нь бий болгосон юм. Төгс Хүчитийн нүд гүнээ шаналсан хүн нэг бүрийг хардаг. Зовж байгаа хүмүүсийн уйлааныг Тэр сонсож, зовлонд нэрвэгдсэн хүмүүсийн ичгүүргүй байдлыг харж, авралын нигүүлслийг алдсан хүн төрөлхтний аргаа барсан байдал, айдас хүйдсийг мэдэрдэг. Хүн төрөлхтөн Түүний халамжаас татгалзаж, өөрсдийнхөө замаар алхахаар сонгож, Түүний нүдний ажиглалтаас булталхаар оролдож, дайсантай хамт гүн тэнгисийн гашуун амтыг эцсийн ганц дуслыг нь хүртэл амтлахыг илүүд үздэг. Төгс Хүчитийн санаа алдалт хүнд сонсогдохоо больсон; Төгс Хүчитийн гар энэхүү эмгэнэлт хүмүүсийг илбэхийг хүсэхээ больсон. Тэрээр удаа дараа буцаан барьж аваад, удаа дараа дахиад л алддаг, Түүний хийдэг ажил ийнхүү давтагддаг. Тухайн мөчөөс эхлээд Тэр ядарч, залхаж эхэлдэг тул хийж буй ажлаа зогсоож, хүн төрөлхтний дунд алхахаа больдог… Хүн эдгээр өөрчлөлтийн алийг нь ч огт мэддэггүй, Төгс Хүчитийн ирж, явж байгааг, мөн Түүний уйтгар гуниг, гансралыг мэддэггүй.

Энэ ертөнцийн бүх зүйл Төгс Хүчитийн бодлын дагуу, Түүний нүдэн дор хурдан өөрчлөгддөг. Хүн төрөлхтний хэзээ ч сонсож байгаагүй зүйлс гэнэтхэн ирж байхад хүн төрөлхтний эртнээс эзэмшсэн зүйлс мэдэгдэлгүйгээр алга болдог. Төгс Хүчитийн хаана байдгийг хэн ч ухан ойлгож чаддаггүй, Төгс Хүчитийн амийн хүчний ер бусын, агуу байдлыг мэдэрч бүр ч чаддаггүй. Хүмүүсийн ухамсарлаж чадахгүй зүйлийг ухамсарлаж чаддаг болохоороо Тэр ер бусын байдаг. Хүн төрөлхтөнд орхигдсон атлаа хүн төрөлхтнийг авардаг Нэгэн болохоороо Тэр агуу байдаг. Тэрээр амьдрал, үхлийн утга учрыг мэддэг, үүнээс гадна, бүтээгдсэн хүн төрөлхтний дагах ёстой оршин тогтнолын хуулийг мэддэг. Тэр бол хүн төрөлхтний оршин тогтнолын суурь, Тэр бол хүн төрөлхтнийг дахин амилуулдаг Золин аврагч юм. Тэрээр Өөрийн ажлын төлөө, Өөрийн төлөвлөгөөний төлөө аз жаргалтай зүрх сэтгэлийг уй гашуугаар дарж, уй гашуутай зүрх сэтгэлийг аз жаргалтай болгодог.

Төгс Хүчитийн амийн хангалтаас холдсон хүмүүс оршин тогтнолын зорилгыг мэддэггүй хэдий боловч үхлээс эмээдэг. Тэд тусламж, дэмжлэггүй байдаг атлаа нүдээ аних дургүй хэвээр бөгөөд энэ дэлхий дээр өөрийн сүнсийг мэдэрдэггүй махан биед өөдгүйгээр оршин тогтнохын тулд өөрсдийгөө хатамжилдаг. Чи ийм

маягаар итгэл найдваргүй, тэр ч тийм маягаар зорилгогүй амьдардаг. Зовлонгийнхоо дунд ёолон, Өөрийнх нь ирэхийг цөхрөнгөө баран хүсэн хүлээж байгаа хүмүүсийг үлгэр домгийн Ариун Нэгэн л аварна. Одоог хүртэл, ухаан алдсан хүмүүст ийм итгэл биеллээ олоогүй. Гэсэн ч хүмүүс ингэж хүсэн эрмэлзсээр байдаг. Гүнээ зовсон энэ хүмүүсийг Төгс Хүчит Нэгэн өршөөдөг; үүний зэрэгцээ, хүмүүсийн хариултыг хэтэрхий удаан хүлээх ёстой байсан тул ухаан алдсан энэ хүмүүсээс Тэр залхсан. Тэр эрж хайхыг хүсдэг, зүрх сэтгэл, сүнсийг чинь эрж хайн, чамайг цаашдаа өлсөж, цангахгүй байгаасай гэсэндээ чамд ус, хоол хүнс авчирч, чамайг сэрээхийг хүсдэг. Эцэж ядран, энэ дэлхийн зэвүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна. Тэр хажууд чинь чамайг ажиглаж, эргэж буцахыг чинь хүлээж байгаа. Бурханаас ирсэн гэдгээ, мөн хэдийд ч юм зүг чигээ алдаж, хэдийд ч юм замдаа ухаан балартаж, хэдийд ч юм “эцэгтэй” болсон гэдгээ ухаарахыг чинь; түүнчлэн Төгс Хүчит эргэн ирэхийг чинь харуулдан хүлээж байсан гэдгийг ухааран, гэнэтхэн ой санамжаа сэргээх өдрийг чинь Тэр хүлээж байна. Тэрээр цөхөрсөн мөрөөсөлтэйгөөр ажигласаар, хариултгүй хариуг хүлээсээр ирсэн. Түүний ажиглалт, хүлээлт үнэлж баршгүй бөгөөд энэ нь хүний зүрх сэтгэл, сүнсний төлөө байдаг. Энэхүү ажиглалт, хүлээлт тодорхой бус хугацаатай байж магадгүй, мөн төгсгөлдөө хүрсэн байж ч магадгүй. Гэхдээ зүрх сэтгэл болон сүнс чинь яг одоо хаана байгааг чи мэдэх ёстой.

2003 оны 5 дугаар сарын 28

ХААНЧЛАЛЫН ЭРИН ҮЕД БУРХАНЫ СОНГОСОН ХҮМҮҮСИЙН ДУУЛГАВАРТАЙ ДАГАХ ЁСТОЙ ЗАХИРГААНЫ АРВАН ЗАРЛИГ

1. Хүн өөрийгөө дөвийлгөж, өргөмжлөх ёсгүй. Бурханыг шүтэн мөргөж, өргөмжлөх ёстой.

2. Бурханы ажилд ашигтай бүхнийг хий, харин Бурханы ажлын ашиг сонирхолд хор хүргэх юуг ч бүү хий. Бурханы нэр, Бурханы гэрчлэл, Бурханы ажлыг хамгаал.

3. Бурханы гэр дэх мөнгө, материаллаг эд зүйл болон бүх эд хөрөнгө нь хүмүүсийн өргөх ёстой тахил юм. Эдгээр тахилыг өөр хэн ч биш, тахилч болон Бурхан л эдэлж болно, учир нь хүний өргөсөн тахил Бурханы таашаалд зориулагддаг. Бурхан эдгээр тахилыг зөвхөн тахилчтай хуваалцдаг ба өөр хэн ч тахилын аль нэг хэсгийг эдлэх эрхгүй, эдлэхэд ч тохирохгүй. Хүний өргөсөн бүх тахил (мөнгө болон эдэлж болох материаллаг эд зүйлийг оролцуулаад) хүнд биш, Бурханд өгөгддөг. Тиймээс, эдгээр зүйлийг хүн эдлэх ёсгүй; хэрвээ хүн эдлэх юм

бол тахил хулгайлж байгаа хэрэг болно. Ийм зүйл хийдэг хэн боловч Иудас юм, учир нь Иудас урвагч байгаад зогсохгүй бас мөнгөний уутанд хийсэн зүйлээс зөвшөөрөлгүй авсан.

4. Хүн ялзарсан зан чанартайгаас гадна сэтгэл хөдлөлтэй байдаг. Ийм болохоор Бурханд үйлчлэх үед эсрэг хүйсийн хоёр гишүүн хоёулхнаа хамт ажиллах туйлаас хориотой. Ийм үйлдэл хийж байгаад баригдсан хэн боловч гарцаагүй хөөгдөнө, хэнийг ч ялгахгүй.

5. Чи Бурханд шүүмжлэлтэй хандах ёсгүй, Бурхантай холбоотой хэрэг явдлыг хамаагүй хэлэлцэж ч болохгүй. Чи хүний хийх учиртай зүйлсийг хийж, хүний ярих учиртайг ярь, харин хэрээс хэтэрч, хил хязгаараа давах ёсгүй. Бурханы зан чанарт халдах зүйл хийхээс сэргийлэхийн тулд хэл үгээ хянаж, зам мөрөө хичээ.

6. Чи хүний хийх учиртай зүйлийг хийж, даалгавраа хэрэгжүүлж, хариуцлагаа биелүүлж, үүргээ гүйцэтгэх ёстой. Чи Бурханд итгэдэг учир Бурханы ажилд хувь нэмрээ оруулах хэрэгтэй; хэрвээ тэгэхгүй бол чи Бурханы үгийг идэж уухад болон Бурханы гэрт амьдрахад тэнцэхгүй.

7. Чи чуулганы ажил болон хэрэг явдалд Бурханд дуулгавартай байхаас гадна, Ариун Сүнсээр ашиглагдсан хүний зааврыг бүх зүйл дээр дага. Өчүүхэн төдий ч зөрчлийг зөвшөөрөхгүй. Чанд дагаж мөрд, харин зөв бурууг бүү шинж; аль нь зөв, аль нь буруу вэ гэдэг нь чамд ямар ч хамааралгүй. Чи бүрэн дуулгавартай байхад л анхаарах ёстой.

8. Бурханд итгэдэг хүмүүс Бурханыг дуулгавартай дагаж, шүтэн мөргөх ёстой. Чи ямар нэг хүнийг өргөмжилж, эсвэл бишрэн шүтэх ёсгүй; чи Бурханыг эн тэргүүнд, хүндэлдэг хүмүүсээ хоёрдугаарт, өөрийгөө гуравдугаарт тавих учиргүй. Ямар ч хүн зүрх сэтгэлд чинь орон зай эзлэх ёсгүй ба чи хүмүүсийг, ялангуяа өөрийнхөө дээдэлдэг хүмүүсийг Бурхантай дүйцүүлж, адилтган бодох ёсгүй. Бурхан үүнийг тэвчихгүй.

9. Ухаан бодлоо чуулганы ажил дээр төвлөрүүл. Махан биеийнхээ хэтийн ирээдүйг хойш тавьж, гэр бүлийн хэрэг явдал дээр шийдэмгий байж, Бурханы ажилд бүхий л зүрх сэтгэлээсээ өөрийгөө зориулж, Бурханы ажлыг эн тэргүүнд тавин, өөрийн амьдралыг хоёрдугаарт тавь. Энэ бол ариун хүний ёс журам юм.

10. Чи итгэл үнэмшилгүй төрөл төрөгсдөө (үр хүүхэд, хань ижил, эгч дүүс, эцэг эх гэх мэт) хүчээр чуулганд оруулах ёсгүй. Бурханы гэр гишүүдээр дутахгүй бөгөөд ашиггүй хүмүүсээр орон тоо дүүргэх хэрэг үгүй. Дуртайяа итгэдэггүй бүх хүнийг чуулган руу хөтлөх ёсгүй. Энэ зарлиг бүх хүнд хамаатай. Энэ талаар та нар бие биеэ хянаж, шалгаж, нэг нэгэндээ сануулж байх ёстой бөгөөд хэн ч үүнийг зөрчиж болохгүй. Итгэл үнэмшилгүй төрөл төрөгсөд чуулганд дурамжхан орж ирсэн ч гэсэн, тэдэнд ном өгч, шинэ нэр оноох ёсгүй; ийм хүмүүс Бурханы гэрт харьяалагддаггүй бөгөөд чуулганд орохыг нь шаардлагатай бүх аргаар зогсоох хэрэгтэй. Хэрвээ чөтгөрүүдийн халдлагаас үүдэн чуулганд хүндрэл учирвал өөрийг чинь чуулганаас хөөж, өөрт чинь хязгаарлалт тогтоох болно. Товчоор хэлбэл, энэ хэрэгт бүх хүн хариуцлага хүлээнэ, гэхдээ чи болчимгүй загнаж, хувийн өс хонзон авахад үүнийг ашиглаж болохгүй.

ХАВСРАЛТ 1
БУРХАНЫ ИЛРЭЛТ ШИНЭ ЭРИН ҮЕИЙГ АВЧИРСАН

Бурханы удирдлагын зургаан мянган жилийн төлөвлөгөө дуусаж байгаа бөгөөд Түүний илрэлтийг эрж хайдаг бүхэнд хаанчлалын үүд хаалга аль хэдийн нээгдээд байна. Хүндэт ах эгч нар аа, та бүхэн юу хүлээгээ вэ? Юу эрж хайгаа вэ? Бурханыг илрэхийг хүлээж байгаа юм уу? Түүний мөрийг хайж байна уу? Бурханы илрэлтийг хэчнээн их хүсэн хүлээдэг билээ! Бурханы мөрийг олох хэчнээн хэцүү билээ! Ийм эрин үед, ийм дэлхий ертөнцөд Бурханы илрэх өдрийг нүдээр үзэхийн тулд бид яах ёстой вэ? Бурханы мөртэй хөл нийлүүлэхийн тулд юу хийх ёстой вэ? Ийм төрлийн асуултууд Бурханыг илрэхийг хүлээж байгаа бүх хүнд тулгардаг. Та бүхэн эдгээрийг нэг бус удаа бодож үзсэн, гэхдээ үр дүн нь юу байв? Бурхан хаана илэрдэг юм бэ? Бурханы мөр хаа байгаа юм бэ? Хариултыг нь та нар олсон уу? “Бурхан Өөрийг нь дагадаг бүх хүний дунд гарч ирдэг, Түүний мөр бидний дунд байдаг; Ийм л энгийн!” гэж олон хүн хариулна; Улиг болсон хариултыг хэн ч өгч чадна, гэхдээ Бурханы илрэлт болон Түүний мөр гэдэг нь юу гэсэн утгатайг та нар ойлгодог уу? Бурханы илрэлт гэдэг нь Тэр газар дэлхий дээр ажлаа хийхээр Өөрөө биечлэн ирэхийг хэлдэг. Тэрээр эрин үеийг эхлүүлж, эрин үеийг төгсгөх ажил явуулахын тулд Өөрийн ялгамж чанар, зан чанартайгаар, мөн Өөрийн төрөлх арга замаар хүн төрөлхтний дунд буудаг. Энэ төрлийн илрэлт нь нэг төрлийн ёслол биш юм. Энэ бол тэмдэг, дүр зураг, гайхамшиг, ямарваа агуу үзэгдэл биш, нэг төрлийн шашны зан үйл ч биш. Энэ бол хэний ч харж, хүрч болох жинхэнэ, бодит баримт билээ. Энэ төрлийн илрэлт нь ёс төдий зүйл хийхийн төлөө, эсвэл богино хугацааны даалгаврын төлөө байдаггүй; харин Түүний удирдлагын төлөвлөгөөний ажлын нэг үе шатны төлөө байдаг. Бурханы илрэлт нь үргэлж утга учиртай байдаг бөгөөд Түүний удирдлагын төлөвлөгөөтэй ямар нэг байдлаар үргэлж холбоотой байдаг. Энд буй илрэлт гээч нь Бурхан хүнийг залж, чиглүүлж, гэгээрүүлдэг төрлийн “илрэлт”-ээс тэс өөр юм. Бурхан Өөрийгөө илчлэх бүрдээ агуу ажлын нэг алхмыг хийдэг. Энэ ажил нь өөр ямар ч эрин үеийн ажлаас өөр билээ. Энэ нь хүний ухаан санаанд багтамгүй ба хүн үүнийг хэзээ ч туулж байгаагүй. Энэ бол шинэ эрин үеийг эхлүүлж, хуучин эрин үеийг төгсгөдөг ажил бөгөөд хүн төрөлхтнийг аврахын төлөө шинэчилж, сайжруулсан ажлын нэг хэлбэр юм; түүнчлэн энэ нь хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү аваачдаг ажил билээ. Энэ бол Бурханы илрэлтийн утга учир юм.

Та нар Бурханы илрэлт гэж юу болохыг ойлгомогцоо Бурханы мөрийг хэрхэн эрж хайх ёстой вэ? Энэ асуултыг тайлбарлахад хэцүү биш: Бурханы илрэлт хаа байна, мөрийг нь тэндээс олох болно. Ийм тайлбар ядах юмгүй сонсогдож болох ч хэрэгжүүлэхэд төдий л амаргүй байдаг, учир нь Бурханыг хаана гарч ирдгийг олон хүн мэддэггүй, Тэр хаана илрэхийг хүсэж байгааг, эсвэл хаана илрэх ёстойг бүр ч мэддэггүй. Ариун Сүнс хаа ажиллаж байна, тэнд Бурхан илэрдэг гэж зарим нь

ойворгоноор итгэдэг. Эсвэл сүнслэг хүмүүс хаа байна, тэнд Бурхан илэрдэг гэж итгэдэг. Эсвэл алдар нэртэй хүмүүс хаа байна, тэнд Бурхан илэрдэг гэж итгэдэг. Ийм итгэл нь зөв, буруу эсэхийг түр хойш тавья. Ийм асуултыг тайлбарлахын тулд бидний зорилго эхлээд тодорхой байх ёстой: Бид Бурханы мөрийг хайж байгаа. Сүнслэг хүмүүсийг эрж хайгаагүй, алдар нэртэй хүмүүсийг бүр ч эрэлхийлээгүй байна; Бурханы мөрийг бид эрэлхийлж байна. Ийм учраас, бид Бурханы мөрийг хайж байгаа тул Бурханы хүсэл, Бурханы үг, айлдварыг хайх нь зохистой—учир нь Бурхан хаана шинэ үгээ хэлнэ, Бурханы дуу хоолой тэнд байх бөгөөд Бурханы мөр хаа байна, Бурханы үйл хэрэг тэнд байдаг. Бурханы илэрхийлэл хаа байна, тэнд Бурхан илэрдэг, Бурхан хаана илэрнэ, тэнд үнэн, зам, амь оршдог. Та нар Бурханы мөрийг эрж хайхдаа “Бурхан бол үнэн, зам, амь” гэх үгийг үл тоомсорлосон. Иймээс олон хүн үнэнийг хүлээн авах үедээ ч гэсэн Бурханы мөрийг олсон гэж боддоггүй бөгөөд Бурханы илрэлтийг бүр ч хүлээн зөвшөөрдөггүй. Ямар ноцтой алдаа гээч! Бурханы илрэлтийг хүний үзэлд нийцүүлэх боломжгүй, Бурхан хүний хүсэлтээр гарч ирэх бүр ч боломжгүй. Бурхан ажлаа хийх үедээ Өөрөө сонголтоо хийж, төлөвлөгөөгөө Өөрөө гаргадаг; түүнчлэн Өөрийн гэсэн зорилго, арга барилтай байдаг. Тэрээр ямар ч ажил хийлээ гэсэн энэ тухай хүнтэй хэлэлцэж, хүний зөвлөгөөг эрж хайх шаардлагагүй, мөн хүн нэг бүрд ажлынхаа талаар мэдэгдэх шаардлага ч байхгүй. Энэ бол хүн бүрийн мэдэх ёстой Бурханы зан чанар юм. Та нар Бурханы илрэлтийг нүдээр үзэж, Бурханы мөрийг дагая гэвэл эхлээд өөрсдийнхөө үзлээс холдох ёстой. Та нар Бурханаас ингэ, тэг гэж шаардах ёсгүй, Түүнийг өөрийнхөө баригдмал сэтгэлгээнд хорьж, үзлээрээ хязгаарлах ч ёсгүй. Харин та нар Бурханы мөрийг хэрхэн хайх ёстой, Бурханы илрэлтийг хэрхэн хүлээн авах ёстой, Бурханы шинэ ажилд хэрхэн захирагдах ёстой талаар өөрсдөөсөө асуух хэрэгтэй; хүний хийх ёстой зүйл бол энэ. Хүн бол үнэн биш, мөн үнэнийг эзэмшдэггүй тул эрж хайж, хүлээн авч, дуулгавартай дагах ёстой.

Чи америк, британи, өөр аль ч үндэстэн бай хамаагүй, өөрийнхөө үндэс угсааны баригдмал байдлаас гарч, өөрийгөө даван, бүтээгдсэн зүйлийн байр сууринаас Бурханы ажлыг харах хэрэгтэй. Ингэснээр чи Бурханы мөрөнд хязгаарлалт тогтоохгүй. Учир нь одоо цагт олон хүн Бурханыг тодорхой нэг улс үндэстэнд, тодорхой нэг ард түмний дунд гарч ирэх боломжгүй гэж үздэг. Бурханы ажлын ач холбогдол хэчнээн гүн гүнзгий, Бурханы илрэлт хэчнээн чухал билээ! Хүний үзэл, бодол тэдгээрийг яаж хэмжиж чадах билээ? Иймээс чи Бурханы илрэлтийг эрж хайхын тулд үндэс угсааныхаа үзлийг эвдэх ёстой гэж Би хэлдэг. Ингэснээр л чи өөрийн үзлээр хязгаарлагдахгүй; ингэснээр л чи Бурханы илрэлтийг угтан авахад тэнцэнэ. Эс бөгөөс мөнхийн харанхуйд үлдэж, Бурханы сайшаалыг хэзээ ч олж авахгүй.

Бурхан бол бүхий л хүн төрөлхтний Бурхан юм. Тэрээр Өөрийгөө ямар ч улс үндэстэн, ард түмний хувийн өмч гэж үздэггүй, харин ямар нэг хэлбэр, улс үндэстэн, ард түмэнд хязгаарлагдалгүйгээр, Өөрийн төлөвлөснөөр ажлаа явуулдаг. Чи магад энэ хэлбэрийг хэзээ ч төсөөлөөгүй байх, эсвэл энэ хэлбэрт

үгүйсгэх хандлагаар ханддаг байх, эсвэл Бурханы Өөрийгөө илчилдэг улс үндэстэн, ард түмэн нь хүн болгонд ялгаварлан гадуурхагддаг, газар дэлхий дээр хамгийн хоцрогдмол байж таардаг байх. Гэвч Бурханд Өөрийн мэргэн ухаан гэж бий. Тэрээр Өөрийн агуу их хүч чадал болон үнэн, зан чанараараа дамжуулан Өөртэй нь нэг санаатай, Өөрийнхөө бүрэн төгс болгохыг хүссэн бүлэг хүмүүсийг үнэнхүү олж авсан—бүх төрлийн шалгалт, гай гамшиг болон бүх төрлийн хавчлагыг туулж, Түүгээр байлдан дагуулагдсан бүлэг Түүнийг эцсээ хүртэл дагаж чаддаг. Ямар нэг хэлбэр, улс үндэстэнд хязгаарлагддаггүй Бурханы илрэлтийн зорилго нь ажлыг төлөвлөснөөрөө гүйцэлдүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Бурхан Иудейд махбод болох үедээ бүхий л хүн төрөлхтнийг золин аврах цовдлолын ажлыг гүйцэлдүүлэх зорилготой байсантай энэ нь яг адилхан. Гэвч Бурхан ийм зүйл хийх боломжгүй гэж иудейчүүд итгэсэн бөгөөд Бурхан махбод болж, Эзэн Есүсийн дүрээр гарч ирэх боломжгүй гэж бодсон юм. Тэдний “боломжгүй” гэдэг нь Бурханыг яллаж, эсэргүүцэх үндэслэл нь болж, эцэстээ Израилыг сүйрэлд хүргэсэн. Өнөөдөр олон хүн үүнтэй төстэй алдаа гаргажээ. Тэд Бурханы илрэлт айсуй гэж бүх чадлаараа тунхагладаг атлаа бас хажуугаар нь Түүний илрэлтийг ялладаг; “боломжгүй” гэх итгэлээрээ тэд Бурханы илрэлтийг дахин нэг удаа баригдмал төсөөлөл дотроо хязгаарладаг. Иймээс Бурханы үгтэй тулгарсныхаа дараа тачигнатал инээд алдах олон хүнийг Би харж байсан. Гэтэл энэ инээд иудейчүүдийн яллалт, доромжлолоос ер нь ялгаатай гэж үү? Та нар үнэний дэргэд хүндлэлгүй загнадаг, хүсэл тэмүүлэлтэй хандлага та нараас бүр ч гардаггүй. Та нар зүгээр л хайнга судалчхаад, санаа амар жаргалтай хүлээж суудаг. Ингэж шинжиж, хүлээснээр юу олж авч чадах юм бэ? Бурханы хувийн удирдамжийг хүлээн авч чадна гэж бодоо юу? Бурханы айлдварыг ялган таньж чадахгүй юм бол чи Бурханы илрэлтийг нүдээр үзэхэд яаж тэнцэх юм бэ? Бурхан хаана илэрнэ, тэнд үнэн илэрхийлэгдэж, Бурханы дуу хоолой тэнд байх болно. Үнэнийг хүлээн зөвшөөрч чаддаг хүмүүс л Бурханы дуу хоолойг сонсож чадах бөгөөд ийм хүмүүс л Бурханы илрэлтийг нүдээр үзэхэд тэнцдэг. Үзлээ хая! Тайван байж, эдгээр үгийг анхааралтай унш. Үнэнийг хүсэн хүлээдэг бол чамайг Бурхан гэгээрүүлэх бөгөөд Түүний хүсэл, Түүний үгийг чи ойлгох болно. “Боломжгүй” гэсэн бодлоо хая! Хүмүүс аливааг боломжгүй гэж итгэх тусам энэ нь болох магадлал өндөртэй байдаг, учир нь Бурханы мэргэн ухаан тэнгэрүүдээс ч дээгүүр, Бурханы бодол хүний бодлоос дээгүүр бөгөөд Бурханы ажил хүний бодол, үзлийн хил хязгаарыг давдаг. Ямарваа зүйл хэдий чинээ боломжгүй байна, эрж хайж болох төдий чинээ их үнэн үүнд байдаг; ямарваа зүйл хэдий чинээ хүний үзэл, төсөөллөөс гадна оршино, Бурханы хүсэл тэнд бүр ч их агуулагдаж байдаг. Учир нь, Өөрийгөө хаана ч илчиллээ гэсэн Бурхан бол Бурхан хэвээр байдаг бөгөөд илрэлтийнх нь байршил, хэв маягаас үүдэн Түүний мөн чанар хэзээ ч өөрчлөгдөхгүй. Мөр нь хаана байгаагаас үл хамааран Бурханы зан чанар нэг янзаараа байдаг, мөр нь хаа ч байлаа гэсэн Тэр бол бүх хүн төрөлхтний Бурхан. Яг л Эзэн Есүс бол зөвхөн израилчуудын Бурхан

бус, Ази, Европ, Америкийн бүх хүний Бурхан төдийгүй, бүхий л орчлон дахь цорын ганц Бурхан гэдэгтэй энэ нь адил билээ. Иймд Бурханы айлдвараас Түүний хүслийг эрж хайж, илрэлтийг нь олж мэдэж, Түүний мөртэй хөл нийлүүлцгээе! Бурхан бол үнэн, зам, амь билээ. Түүний үг, илрэлт зэрэгцэн оршдог бөгөөд Түүний зан чанар болон мөр хүн төрөлхтөнд цаг үргэлж нээлттэй байдаг. Хүндэт ах эгч нар аа, та нар эдгээр үгээс Бурханы илрэлтийг харж, шинэ эрин үе рүү алхахдаа Түүний мөрийг дагаж эхлэн, илрэлтийг нь хүлээдэг хүмүүст зориулан Бурханы бэлдсэн үзэсгэлэнтэй сайхан шинэ тэнгэр, газарт орж чадна гэж Би найдаж байна!

ХАВСРАЛТ 2
БҮХ ХҮН ТӨРӨЛХТНИЙ ХУВЬ ЗАЯАГ БУРХАН ЗАХИРДАГ

Хүн төрөлхтний гишүүд ба үнэн сүсэгт Христэд итгэгчид болохын хувьд өөрсдийн оюун санаа, бие махбодыг Бурханы даалгаврыг биелүүлэхэд зориулах нь бид бүгдийн үүрэг, хариуцлага юм. Учир нь бидний бүх оршихуй Бурханаас ирсэн бөгөөд Бурханы дээд эрхийн ачаар оршдог билээ. Хэрвээ оюун санаа, бие махбод маань Бурханы даалгавар болон хүн төрөлхтний зөв шударга үйл хэргийн төлөө зориулагдахгүй бол бидний сүнс Бурханы даалгаврын төлөө амиа золиосолсон хүмүүсээс, тэр тусмаа биднийг бүх зүйлээр хангасан Бурханаас ичнэ.

Бурхан энэ ертөнцийг бүтээсэн, энэ хүн төрөлхтнийг бүтээсэн, түүнчлэн эртний Грекийн соёл, хүний соёл иргэншлийн зохион бүтээгч нь Тэр байсан. Бурхан л энэ хүн төрөлхтнийг тайтгаруулж, Бурхан л энэ хүн төрөлхтөнд өдөр, шөнөгүй санаа тавьдаг. Хүн төрөлхтний хөгжил, дэвшил нь Бурханы дээд эрхээс салшгүй, хүний түүх болон ирээдүй Бурханы зохиомжоос салшгүй билээ. Хэрвээ чи жинхэнэ Христэд итгэгч бол аливаа улс, үндэстний мандаж, доройтох нь Бурханы зохиомжийн дагуу явагддаг гэдэгт лавтай итгэнэ. Бурхан л ганцаараа аливаа улс, үндэстний хувь заяаг мэддэг ба Бурхан ганцаараа энэ хүн төрөлхтний амьдралын замналыг хянадаг. Хэрвээ хүн төрөлхтөн сайн хувь заяатай байхыг хүсвэл, хэрвээ улс орон сайн хувь заяа хүсэж байвал хүн Бурханыг шүтэн мөргөж, Бурханы өмнө гэмшиж, нүглээ улайх ёстой, эс бөгөөс хүний хувь заяа, хүрэх газар гамшиг сүйрлээр дуусах нь гарцаагүй.

Ноагийн бүхээг барьсан цаг үеийг эргэн хар: Хүн төрөлхтөн гүн ялзарсан, Бурханы ерөөлийн замаас гажиж, Бурханаар халамжлуулахаа больсон, Бурханы амлалтыг алдчихсан байсан. Тэд Бурханы гэрэлгүйгээр харанхуйд амьдарч байв. Тиймээс тэд садар самуун уг чанартай болж, жигшүүрт доройтолд өөрсдийгөө хаясан байв. Тийм хүмүүс Бурханы амлалтыг хүлээж авч чадахааргүй болсон; тэд Бурханы нүүрийг харахад ч, Бурханы дуу хоолойг сонсоход ч тохирохгүй байлаа. Учир нь тэд Бурханыг хаяж, Түүний хайрласан бүх зүйлийг орхиж, Бурханы сургаалыг мартчихсан байсан юм. Тэдний зүрх сэтгэл Бурханаас улам бүр

холдсоноор тэд хамаг эрүүл ухаан, хүн чанараа алдан доройтож, улам ёрын муу болсон юм. Тиймээс тэд үхэл рүүгээ бүр ч ойртож, Бурханы уур хилэн, шийтгэлийг хүртсэн. Ноа л Бурханд шүтэн мөргөж, муугаас зайлсан учир Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы зааврыг сонсож чаджээ. Ноа Бурханы үгийн зааврын дагуу бүхээг барьж, бүх төрлийн амьтдыг цуглуулсан. Ингээд бүх зүйл бэлэн болсны дараа Бурхан дэлхий дээр сүйрлээ эхлүүлсэн. Ноа болон түүний гэр бүлийн долоон гишүүн л сүйрлээс амь гарсан, учир нь Ноа Еховаг шүтэн мөргөж, муугаас зайлсан билээ.

Өнөө үеийг одоо хар л даа: Бурханд шүтэн мөргөж муугаас зайлж чадах Ноа шиг зөв шударга хүмүүс байхаа больжээ. Гэсэн ч Бурхан хүн төрөлхтөнд нигүүлсэнгүй хэвээр, энэхүү төгсгөлийн эрин үед тэднийг уучилсаар байдаг. Өөрийг нь гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Бурхан эрж хайдаг. Өөрийнх нь үгийг сонсож чаддаг, Түүний даалгаврыг мартаагүй, зүрх сэтгэл, бие махбодоо Түүнд өргөн барьдаг хүмүүсийг Тэр эрж хайдаг. Өөрийнх нь өмнө хүүхэд шиг дуулгавартай байдаг, Өөрийг нь эсэргүүцдэггүй хүмүүсийг Тэр эрж хайдаг. Хэрвээ чи аливаа хүчнээс ангид байж Бурханд өөрийгөө зориулдаг бол Бурхан чамд энэрэнгүй хандаж, ерөөлөө хайрлана. Чи өндөр байр суурьтай, нэр хүндтэй, арвин мэдлэгтэй, элбэг их эд хөрөнгийн эзэн, олон дэмжигчтэй байсан ч эдгээр зүйл нь Бурханы дуудлага болон даалгаврыг хүлээн авч, Бурханы чамаас хүссэн зүйлийг хийхээр Бурханы өмнө очиход чинь саад болохгүй байвал чиний хийж байгаа бүхэн дэлхий дээрх хамгийн чухал ач холбогдолтой, мөн хүн төрөлхтний хамгийн зөв шударга үйл хэрэг байх болно. Хэрвээ чи өөрийн байр суурь, зорилгын төлөө Бурханы дуудлагаас татгалзвал хийсэн бүхэн чинь хараагдаж, бүр Бурханд жигшигдэнэ. Магадгүй чи ерөнхийлөгч, эрдэмтэн, пастор, эсвэл ахлагч байж болно, гэхдээ үйл хэрэгтээ зөвхөн өөрийн мэдлэг, чадварт найдвал чиний албан тушаал хэр өндөр байхаас үл хамааран үргэлж бүтэлгүйтэж, үргэлж Бурханы ерөөлөөр дутагдана, учир нь Бурхан чиний хийдэг юуг ч хүлээн зөвшөөрдөггүй, мөн чиний үйл хэргийг зөв шударга гэж зөвшөөрч, эсвэл чамайг хүн төрөлхтний тусын тулд ажиллаж байна гэж хүлээн зөвшөөрдөггүй. Чи Бурханы хамгаалалтаас хүнийг холдуулахын тулд хүн төрөлхтний мэдлэг, хүч чадлыг ашиглахаас өөрийг хийдэггүй, мөн Бурханы ерөөлийг үгүйсгэхийн тулд үүнийг хийдэг гэж Тэр хэлнэ. Хүн төрөлхтнийг харанхуй руу, үхэл рүү, мөн Бурханыг болон Түүний ерөөлийг алдсан хязгаргүй оршин тогтнолын эхлэл рүү хөтөлж байна гэж Тэр чамайг хэлнэ.

Хүн төрөлхтөн нийгмийн шинжлэх ухааныг үүсгэсэн цагаас хойш хүний оюун санаа шинжлэх ухаан болон мэдлэгт эзэмдүүлсэн юм. Тэгээд шинжлэх ухаан, мэдлэг нь хүн төрөлхтнийг удирдах хэрэгсэл болсон ба хүнд Бурханыг шүтэн мөргөх орон зай хангалттай байхаа больж, Бурханыг шүтэн мөргөх таатай нөхцөл үгүй болсон. Хүний зүрх сэтгэл дэх Бурханы байр суурь улам доошилжээ. Зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй болохоор хүний дотоод ертөнц харанхуй, итгэл найдваргүй агаад хоосон. Иймээс ч хүн төрөлхтний оюун ухаан, зүрх сэтгэлийг дүүргэхийн тулд, Бурхан хүнийг бүтээсэн гэх үнэнтэй зөрчилддөг нийгмийн

шинжлэх ухааны онолууд, хүний хувьслын онол болон бусад онолыг илэрхийлэхээр нийгмийн ухааны эрдэмтэн, түүхч, улс төрчид олноор гарч ирсэн билээ. Ийнхүү Бурхан бүхнийг бүтээсэн гэдэгт итгэдэг хүмүүс ихэд цөөрч, хувьслын онолд итгэгчдийн тоо бүр олширсон. Бурханы ажлын тухай тэмдэглэл, Хуучин гэрээний үеийн Түүний үгийг улам олон хүн үлгэр, домог мэтээр үздэг болсон. Хүмүүс зүрх сэтгэлдээ Бурханы агуу байдал болон эрхэм чанарыг, Бурхан оршдог бөгөөд бүх зүйлийг ноёрхдог гэдэг итгэл үнэмшлийг хайхрахаа байсан. Хүн төрөлхтний үхэх сэхэх, улс, үндэстний хувь заяа ч тэдэнд чухал биш болсон. Хүн идэж, уух, зугаа цэнгэл хөөцөлдөхийг л боддог хоосон ертөнцөд амьдардаг… Бурхан өнөөдөр хаана ажлаа хийдгийг эрж хайх, эсвэл Тэр хүний хүрэх газрыг хэрхэн захирч зохицуулж байдгийг хайх санаачилга гаргадаг хүн цөөхөн байдаг. Ийм маягаар хүнийг анзаараа ч үгүй байхад хүн төрөлхтний соёл иргэншил улам л хүний хүсэлд нийцэхээргүй болж байгаа бөгөөд бүр ч олон хүн ийм ертөнцөд амьдарснаараа аль хэдийн өнгөрөн одсон хүмүүсээс ч дор аз жаргалгүй байгаагаа мэдрэх болжээ. Урьд нь өндөр соёл иргэншилтэй байсан орнуудын хүмүүс хүртэл ийм гомдол тоочиж байна. Учир нь, Бурхан залж чиглүүлэхгүй л бол хүн төрөлхтний соёл иргэншлийг хадгалж үлдэхийн тулд эрх баригчид, нийгэм судлаач нар тархиа хэчнээн их гашилгавч тусыг эс олно. Хэн ч хүний амь байж чадахгүй учраас хэн ч хүний зүрх сэтгэл дэх хоосныг дүүргэж чадахгүй, ямар ч нийгмийн онол хүнийг зовоож буй хоосон байдлаас нь салгаж чадахгүй. Шинжлэх ухаан, мэдлэг, эрх чөлөө, ардчилал, таашаал, тав тух гэх мэт эдгээр зүйл хүнд зөвхөн түрхэн зуурын тайтгарал өгдөг. Эдгээр зүйл байсан ч хүмүүс гарцаагүй нүгэл үйлдэж, нийгмийн шударга бус байдалд гомдоллосон хэвээр байх болно. Эдгээр зүйл хүний эрэл хайгуул хийх хүсэл, хорхойслыг барьж чадахгүй. Учир нь хүнийг Бурхан бүтээсэн бөгөөд утга учиргүй золиос, эрэл хайгуул нь хүнийг илүү их гуниг зовлон руу л хөтөлж, хүн төрөлхтний ирээдүй эсвэл угтах замтай хэрхэн нүүр тулахаа мэдэхгүй байнгын айдастай оршин байхад хүргэдэг юм. Тэр ч бүү хэл, хүн шинжлэх ухаан, мэдлэгээс айдаг, хоосон мэдрэмжээс бүр ч их айдаг болно. Энэ дэлхийд, эрх чөлөөтэй оронд байна уу, эсвэл хүний эрх үгүй оронд амьдарч байна уу гэдгээс үл хамааран чи хүн төрөлхтний хувь заяанаас зугтаж огтхон ч чадахгүй. Чи захирагч, захирагдагчийн аль нь ч бай, хүн төрөлхтний хувь заяа, нууц, хүрэх газрыг судалж шинжлэх хүслээс зугтаж огтхон ч чадахгүй, хоосон байдлын толгой эргэм мэдрэмжээс зугтаж бүр ч чадахгүй. Бүх хүн төрөлхтөнд нийтлэг байдаг ийм үзэгдлийг нийгэм судлаачид нийгмийн үзэгдэл гэж нэрлэдэг хэдий ч ийм асуудлыг шийдвэрлэхээр гарч ирж чадах агуу хүн алга л байна. Эцсийн эцэст хүн бол хүн бөгөөд Бурханы байр суурь болон амийг ямар ч хүн орлож чадахгүй. Хүн төрөлхтөнд, зүгээр нэг хүн бүр цатгалан, эрх тэгш, чөлөөтэй байх шударга нийгэм шаардлагатай байгаа юм биш; хүн төрөлхтөнд хэрэгтэй байгаа зүйл бол Бурханы аврал болон Түүний өгдөг амийн хангалт юм. Бурханы аврал болон Түүний амийн хангалтыг хүртэж байж л хүний хэрэгцээ, эрж хайх хүсэл, сүнсний хоосон мэдрэмж

нь шийдэгдэж чаддаг. Хэрвээ улс, үндэстний хүмүүс Бурханы аврал, халамжийг хүлээн авч чадахгүй бол тэр улс, үндэстэн доройтлын замаар харанхуй руу алхаж, Бурханаар устгагдах болно.

Танай улс эдүгээ дээшлэн дэвжиж байж магадгүй ч чи өөрийн ард түмэнд Бурханаас төөрч холдохыг зөвшөөрвөл улс чинь Бурханы ерөөлийг улам л алдаж байгаагаа харна. Улсын чинь соёл иргэншил улам бүр хөл доор гишгэгдэж, тун удалгүй хүмүүс Бурханы эсрэг босож, Тэнгэрийг хараах болно. Тэгээд улс орны хувь заяа нэг мэдэхэд сүйрнэ. Бурханд хараагдсан тэдгээр улсад арга хэмжээ авахын тулд Бурхан хүчирхэг улсуудыг бий болгох ба тэднийг бүр газрын хөрснөөс арчиж ч магадгүй. Нэг улс, үндэстний мандаж, доройтох нь тухайн орны удирдагчид Бурханыг шүтэн мөргөдөг эсэхээс, ард иргэдээ Бурханд илүү ойр, Түүнд шүтэн мөргөдөг болгоход залдаг эсэхээс хамаардаг. Гэвч өнөөгийн энэ сүүлчийн эринд Бурханыг шүтдэг, Түүнийг жинхэнээсээ хайдаг хүмүүс улам цөөрсөн учраас Христийн шашныг улсынхаа шашин болгосон орнуудад Бурхан онцгой ивээл хайрладаг. Тэрээр дэлхийн харьцангуй зөв шударга хүрээг байгуулахын тулд тэдгээр улсыг нэгтгэдэг байхад харин бурхангүй үзэлтэй юм уу жинхэнэ Бурханыг шүтэн мөргөдөггүй орнууд зөв шударга хүрээний дайснууд болдог. Ийм маягаар, Бурхан хүн төрөлхтний дунд Өөрийн ажлыг явуулах газартай болоод зогсохгүй, мөн Бурханыг эсэргүүцдэг улс оронд хориг, хязгаарлалт тавихын тулд зөв шударга эрх мэдлийг хэрэгжүүлж чадах улс орныг олж авдаг. Гэвч тэглээ гээд илүү олон хүн Бурханыг шүтэн мөргөхөөр ирэхгүй л байна. Яагаад гэвэл, хүн Бурханаас хэтэрхий холдчихсон бөгөөд хүн Бурханыг мартаад дэндүү удаж байгаа юм. Зөв шударга байдлыг хэрэгжүүлж, зөв шударга бус байдлаас татгалздаг тийм орнууд л газар дэлхий дээр үлддэг. Гэвч энэ нь Бурханы хүслээс хол байдаг, учир нь ямар ч орны удирдагчид ард иргэдийг нь Бурхан захирахыг зөвшөөрөхгүй, ямар ч улс төрийн нам Бурханд шүтэн мөргөхийн тулд хүмүүсээ цуглуулахгүй; Бурхан улс орон, үндэстэн, эрх баригч нам бүрийн, тэр ч бүү хэл хүн бүрийн зүрхэнд эзлэх зүй ёсны байраа алдчихсан. Энэ дэлхий дээр зөв шударга хүчнүүд оршдог хэдий ч хүний зүрх сэтгэлд Бурханы эзлэх орон зай байдаггүй засаглал бол хэврэг юм. Бурханы ерөөлгүйгээр улс төрийн талбар эмх замбараагаа алдаж, ганц цохилт ч дааж чадахааргүй болно. Хүн төрөлхтний хувьд, Бурханы ерөөлгүйгээр байна гэдэг нарны гэрэлгүйгээр байхтай адилхан. Улс гүрний удирдагчид ард түмэндээ хэчнээн их хувь нэмэр оруулаа гээд, хэчнээн олон зөв шударга хурал зөвлөгөөн хийлээ гээд, аль нь ч урсгалын чиглэлийг өөрчилж чадахгүй, эсвэл хүн төрөлхтний хувь заяаг өөрчилж чадахгүй. Ард иргэд нь хоол унд, хувцас хунартай, хамтдаа энх амгалан суудаг улсыг сайн улс, сайн удирдагчидтай гэж хүмүүс боддог. Гэвч Бурхан тэгж боддоггүй. Өөрийг нь нэг ч хүн шүтэн мөргөдөггүй улс орон бол Өөрийнх нь устгах улс мөн гэж Тэр итгэдэг. Хүний санал бодол Бурханыхаас дэндүү их зөрдөг. Тиймээс хэрвээ улсын тэргүүн нь Бурханыг шүтэн мөргөдөггүй бол уг улсын хувь заяа эмгэнэлтэй болох бөгөөд тэр улс ямар ч хүрэх газаргүй байх болно.

Бурхан хүн төрөлхтний улс төрийн хэрэгт оролцдоггүй боловч улс, үндэстний хувь заяаг удирддаг. Бурхан энэ дэлхийг, бүхэл орчлон ертөнцийг удирддаг. Хүний хувь заяа, Бурханы төлөвлөгөө нь нарийн уялдаа холбоотой бөгөөд ямар ч хүн, улс, эсвэл үндэстэн Бурханы дээд эрхээс ангид байдаггүй. Хэрвээ хүн өөрийнхөө хувь заяаг мэдэхийг хүсвэл Бурханы өмнө ирэх ёстой. Бурхан Өөрийг нь дагаж, шүтэн мөргөдөг хүмүүсийг өөд нь татах ба эсэргүүцэж, голдог хүмүүст доройтол, мөхөл авчирна.

Библид өгүүлсэн Бурхан Содомыг сүйрүүлсэн явдлыг санаж, Лотын эхнэр хэрхэн давсан багана болсныг бод. Ниневегийн хүмүүс хэрхэн үнс, тааран дотор нүглээ гэмшсэнийг эргээд бод, 2,000 жилийн өмнө иудейчүүд Есүсийг загалмайд цовдолсны дараа тэдэнд юу тохиолдсоныг сана. Иудейчүүд Израилиас хөөгдөж, дэлхий дахины улсууд руу зугтсан билээ. Олонх нь хөнөөгдөж, бүхий л Иудей үндэстэн улс орон нь сүйрсэн, урьд хожид байгаагүй шаналлыг амссан. Тэд Бурханыг загалмайд цовдолж, жигшүүрт нүгэл үйлдэж, Бурханы зан чанарыг хилэгнүүлсэн. Тэд хийсэн хэргийнхээ төлөөсийг төлж, өөрсдийнхөө үйлдлийн үр дагаврыг үүрэх болсон. Тэд Бурханыг яллаж, голсон, иймээс тэдэнд Бурханаар шийтгүүлэх хувь заяа л үлдсэн юм. Энэ бол удирдагчдынх нь ард түмэндээ авчирсан гашуун үр дагавар, гамшиг билээ.

Өнөөдөр, Бурхан Өөрийн ажлыг хийхээр дэлхийд эргэж ирсэн. Түүний эхний зогсоол бол дарангуй засаглалын үлгэр жишээ болсон газар буюу бурхангүй үзлийн бат бэх цайз, Хятад юм. Бурхан Өөрийн мэргэн ухаан, хүч чадлаар бүлэг хүмүүсийг олж авсан. Энэ хугацаанд Хятадын эрх баригч нам Түүнийг бүх аргаар мөшгөн хөөж, асар их зовлон амсуулан толгой тавьж амрах газар, орох оронгүй болгосон. Тэгсэн ч гэсэн Бурхан хийхээр зорьсон ажлаа хийсээр байна: Тэр Өөрийн дуу хоолойг хүргэхээр айлдаж, сайн мэдээ түгээж байна. Бурханы төгс хүчийг хэн ч төсөөлж чадахгүй. Хятадад буюу Бурханыг дайсан гэж үздэг улсад Бурхан Өөрийнхөө ажлыг хэзээ ч зогсоогоогүй. Харин ч илүү олон хүн Бурханы ажил ба үгийг хүлээн авсан, учир нь Бурхан хүн төрөлхтний гишүүн нэг бүрийг боломжит хамгийн дээд хэмжээнд авардаг. Ямар ч орон, ямар ч хүч Бурханы биелүүлэхээр хүссэн зүйлд саад болж чадахгүй гэж бид итгэдэг. Бурханы ажилд саад хийдэг, Бурханы үгийг эсэргүүцдэг, Бурханы төлөвлөгөөг үймүүлж, сүйтгэдэг хүмүүс эцэстээ Бурханаар шийтгүүлнэ. Бурханы ажлыг эсэргүүцдэг хүн там руу илгээгдэнэ; Бурханы ажлыг сөрдөг ямар ч улс устгагдана; Бурханы ажлыг эсэргүүцэхээр бослого гаргадаг ямар ч үндэстэн газрын хөрснөөс арчигдаж, оршин тогтнохоо болино. Би бүх үндэстэн, улс орон, тэр ч байтугай бүх салбарын хүмүүсийг, Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы ажлыг харж, хүн төрөлхтний хувь заяанд анхаарлаа хандуулж, Бурханыг хамгийн ариун, хамгийн хүндтэй, хамгийн дээд бөгөөд хүн төрөлхтний дунд шүтэгдэх цорын ганц объект болгож, бүх хүн төрөлхтөнд Бурханы ерөөл дор яг л Абрахамын үр удам Еховагийн амлалт дор амьдарч байсан шиг, Бурханы анх бүтээсэн Адам, Ева хоёр Еден цэцэрлэгт амьдарч байсан шиг амьдрах боломж олгохыг шавдуулж байна.

Бурханы ажил яг л сүрлэг давлагаа мэт нөмрөн ирдэг. Хэн ч Түүнийг саатуулан барьж чадахгүй, хэн ч Түүний алхааг зогсоож чадахгүй. Түүний үгийг анхааралтайгаар сонсдог, Түүнийг эрж хайж, Түүгээр цангадаг хүмүүс л Түүний мөрийг дагаж, Түүний амлалтыг хүлээн авч чадна. Харин тэгээгүй хүмүүс дааж давшгүй гамшигт өртөж, яг тохирох шийтгэлээ хүртэнэ.

ХАВСРАЛТ 3
ХҮН БУРХАНЫ УДИРДЛАГА ДУНД Л АВРАГДАЖ ЧАДНА

Бурханы удирдлага өөрсөдтэй нь огтхон ч холбоогүй гэж хүмүүс боддог учраас хүн нэг бүрийн нүдээр бол Бурханы удирдлага тун танил бус зүйл юм. Бурханы удирдлага бол ганцхан Бурханы ажил, Бурханы Өөрийнх нь хэрэг гэж хүмүүс боддог—иймээс хүн төрөлхтөн Түүний удирдлагыг хайхардаггүй. Ийм маягаар хүн төрөлхтний аврал тодорхойгүй, бүрхэг болсон ба одоо энэ нь хоосон гоё үг төдийхөн байдаг. Аврал хүртэж, гайхалтай сайхан хүрэх газарт орохын тулд хүн Бурханыг дагадаг хэдий ч Бурхан ажлаа хэрхэн явуулдгийг огт анхаардаггүй. Бурхан юу төлөвлөснийг хүн тоодоггүй, аврагдахын тулд гүйцэтгэх ёстой үүргээ ч тоодоггүй. Энэ үнэхээр эмгэнэлтэй. Хүний авралыг Бурханы удирдлагаас тусгаарлаж болохгүй, Бурханы төлөвлөгөөнөөс ч салгаж болохгүй. Гэсэн ч хүн Бурханы удирдлагын талаар юу ч боддоггүй, тиймээс Бурханаас улам бүр холддог. Энэ нь бүтээл гэж юу болох, Бурханд итгэх гэж юу болох, Бурханд хэрхэн шүтэн мөргөх гэх мэт авралын асуулттай нягт холбоотой асуудлуудыг огт мэддэггүй улам олон тооны хүмүүсийг Түүнийг дагагчдын эгнээнд нэгдэхэд хүргэсэн юм. Тэгэхээр Бурханыг дагаж, Түүнд итгэх нь юу гэсэн үг болохыг Түүний дагагч бүрд тодорхой ойлгуулахын тулд бид одоо Бурханы удирдлагын талаар ярилцах ёстой. Ингэх нь, ердөө ерөөл хүртэх, гай гамшгаас зайлсхийх, эсвэл бусдаас ялгарахын тулд Бурханыг дагахын оронд явах ёстой замаа илүү зөв сонгоход нь хүн бүрд тусална.

Хэдий Бурханы удирдлага гүн гүнзгий ч хүн ойлгохын аргагүй биш юм. Учир нь Бурханы бүх ажил Түүний удирдлага болон хүн төрөлхтнийг аврах ажилтай нь холбоотой байдаг бөгөөд хүн төрөлхтний амь, амьдрал, хүрэх газартай хамаатай байдаг. Хүмүүсийн дунд болон хүн дээр Бурханы хийдэг ажлыг маш бодитой, утга учиртай гэж хэлж болно. Үүнийг хүн харж, туулж болох ба хийсвэр зүйл огт биш. Хэрвээ хүн Бурханы хийдэг бүх ажлыг хүлээн авч чаддаггүй бол Түүний ажлын ач холбогдол юу вэ? Тийм удирдлага хүнийг яаж авралд хөтөлж чадах вэ? Бурханыг дагадаг олон хүн хэрхэн ерөөл хүртэх, эсвэл гай гамшгаас хэрхэн зайлсхийх талаар л анхаардаг. Бурханы ажил болон удирдлагыг дурдмагц тэд дуугаа хурааж, огт сонирхохоо больдог. Тийм залхмаар асуултуудыг ойлгох нь тэдний амийг өсөхөд туслахгүй, эсвэл ямар ч ашиг тус өгөхгүй гэж тэд боддог. Иймээс тэд Бурханы удирдлагын тухай мэдээг сонссон хэдий ч багахан анхаарал хандуулдаг.

Тэд үүнийг хүлээн авах эрхэм нандин зүйл гэж үздэггүй, өөрсдийн амийн нэг хэсэг гэж бүр ч хүлээн авдаггүй. Тийм хүмүүст Бурханыг дагах энгийн нэг зорилго л байдаг бөгөөд тэр зорилго нь ерөөл хүртэх явдал юм. Ийм хүмүүс энэхүү зорилгыг шууд агуулдаггүй өөр ямар ч зүйлд анхаарал хандуулан яршиг удаж чаддаггүй. Тэдний хувьд, ерөөл хүртэхийн тулд Бурханд итгэхээс илүү зөв зүйтэй зорилго үгүй—энэ нь тэдний итгэлийн жинхэнэ үнэ цэн юм. Хэрвээ ямар нэг зүйл энэ зорилгод нь нэмэр болдоггүй бол үүнд тэдний сэтгэл огт хөдөлдөггүй. Өнөөдөр Бурханд итгэдэг ихэнх хүмүүсийн хувьд ийм л байдаг. Тэдний зорилго болон санаархал зөв зүйтэй мэт харагддаг, учир нь Бурханд итгэхийн зэрэгцээ тэд бас Бурханы төлөө зарлагадаж, өөрсдийгөө Бурханд зориулж, үүргээ биелүүлдэг. Тэд залуу насаа орхиж, гэр бүл, ажил мэргэжлээ хаяж, тэр ч байтугай олон жилийг гэрээсээ хол завгүй өнгөрүүлдэг. Өөрсдийн эцсийн зорилгын төлөө тэд дур сонирхол, амьдралыг үзэх үзэл, тэр ч бүү хэл эрэл хайгуулын чиглэлээ өөрчилдөг; гэхдээ Бурханд итгэх итгэлийнхээ зорилгыг өөрчилж чаддаггүй. Тэд өөрсдийн туйлын зорилгыг удирдахын төлөө ийш тийш гүйдэг; зам хэчнээн хол байсан ч хамаагүй, замд нь хэчнээн их зовлон бэрхшээл, саад тотгор байх нь хамаагүй, тэд цөхрөлтгүй зүтгэж, үхлээс айдаггүй. Ямар хүч тэднийг ийм маягаар өөрсдийгөө үргэлжлүүлэн зориулахад хүргэдэг вэ? Тэдний мөс чанар уу? Агуу, жудагтай байдал нь уу? Ёрын муу хүчтэй эцсээ хүртэл тэмцэх шийдвэр нь үү? Шагнал эрэлхийлэлгүйгээр Бурханд гэрчлэл хийх тэдний итгэл үү? Бурханы хүслийг биелүүлэхийн тулд бүхнээ орхиход бэлэн үнэнч сэтгэл нь үү? Эсвэл хэрээс хэтэрсэн хувийн шаардлагаас үргэлж татгалзсан тэдний зориулалтын сэтгэл үү? Бурханы удирдлагын ажлыг хэзээ ч ойлгож байгаагүй хүний хувьд тийм их хүчин чармайлт гаргана гэдэг бол үнэхээр л гайхамшиг юм! Энэ хүмүүс хэчнээн ихийг зориулсныг одоохондоо хэлэлцэхээ больё. Гэсэн ч тэдний үйлдлийг задлан шинжлэвээс тун зохилтой. Бурханыг хэзээ ч ойлгоогүй хүмүүс Бурханы төлөө яагаад маш ихийг зориулдаг вэ гэдэгт, өөрсөдтэй нь нягт холбоотой ашиг тусаас гадна өөр ямар нэгэн шалтгаан байж болох уу? Үүнээс бид урьд нь таниагүй нэг асуудлыг олж илрүүлдэг: Бурхантай харилцах хүний харилцаа нь ердөө л цэвэр хувийн ашиг сонирхлын харилцаа юм. Энэ нь ерөөл хүлээн авагч болон өгөгчийн хоорондох харилцаа билээ. Шуудхан хэлэхэд, энэ нь ажил олгогч болон ажилтны хоорондох харилцаатай адилхан. Ажилтан нь ажил олгогчийн өгч буй шагналыг хүлээн авахын тулд л ажилладаг. Ийм харилцаанд ямар ч хайр энэрэл байдаггүй, зөвхөн наймаа л байдаг. Хайрлаж, хайрлуулах явдал байхгүй, өглөг болон өршөөл л байдаг. Ямар ч ойлголцол байдаггүй, дарлагдсан дургүйцэл, хууран мэхлэлт л байдаг. Ойр дотно байдал байдаггүй, гэтлэхийн аргагүй ангал л байдаг. Нөхцөл байдал иймдээ тулахад хэн ийм чиг хандлагыг өөрчилж чадах вэ? Энэхүү харилцаа нь хэр аймшигтай болсныг хэчнээн хүн үнэхээр ойлгож чадах вэ? Хүмүүс ерөөгдөхийн баяр баясалд умбах үед, Бурхантай харилцах тийм харилцаа нь хэчнээн ичгэвтэр, үзэшгүй муухай болсныг хэн ч төсөөлж чадахгүй гэдэгт Би итгэж байна.

Хүн төрөлхтний Бурханд итгэх итгэлийн талаарх хамгийн гунигтай зүйл бол, хүн Бурханы ажлын дунд өөрийн удирдлагыг явуулдаг атлаа Бурханы удирдлагыг огт анхаардаггүй. Хүний хамгийн том бүтэлгүйтэл нь, Бурханд захирагдаж, Түүнд шүтэн мөргөхөөр эрэлхийлэхийн зэрэгцээ өөрийн хүслэнт хүрэх газрыг бүтээн, хамгийн агуу ерөөл, хамгийн сайн хүрэх газрыг хэрхэн авах вэ гэж хуйвалдаж байдагт оршино. Хүн хэчнээн арчаагүй, жигшүүртэй, өрөвдмөөр гэдгээ ойлгодог ч гэсэн хэчнээн хүн өөрсдийн туйлын хүслэн, итгэл найдварыг амархан орхиж чадах билээ? Хэн алхаагаа зогсоож, зөвхөн өөрийгөө л бодохоо больж чадах билээ? Өөрийнхөө удирдлагыг гүйцэлдүүлэхийн тулд Өөртэй нь ойр хамтран ажиллах хүмүүс Бурханд хэрэгтэй байдаг. Түүний удирдлагын төлөвлөгөөний ажилд бүх бие, сэтгэлээ зориулснаар Түүнд дуулгавартай байх хүмүүс Түүнд хэрэгтэй байдаг. Харин өдөр бүр алгаа тосон Түүнээс юм гуйдаг хүмүүс Түүнд хэрэггүй, багыг өгөөд шагнуулахаар хүлээдэг хүмүүс бүр ч хэрэггүй. Ялихгүй хувь нэмэр оруулчхаад үүндээ эрддэг хүмүүсийг Бурхан үзэн яддаг. Түүний удирдлагын төлөвлөгөөний ажилд дургүйцдэг ба тэнгэрт очиж, ерөөл хүртэх талаар л ярихыг хүсдэг хүйтэн цустай хүмүүсийг Тэр үзэн яддаг. Хүн төрөлхтнийг аврахын тулд Түүний хийдэг ажлаас үүссэн боломжийг далимдуулдаг хүмүүсийг Тэр бүр их зэвүүцдэг. Учир нь, Өөрийнхөө удирдлагын төлөвлөгөөний ажлаар дамжуулан Бурхан юу биелүүлж, юунд хүрэхийг хүсдэг талаар энэ хүмүүс хэзээ ч анхаарч байгаагүй. Тэд ерөөл хүртэхийн тулд Бурханы ажлаас гарах боломжийг хэрхэн ашиглаж болох талаар л анхаардаг. Тэд Бурханы зүрх сэтгэлийг огт хайхардаггүй, гагцхүү өөрсдийнхөө хэтийн ирээдүй, хувь заяаг анхаарч байдаг. Бурханы удирдлагын төлөвлөгөөний ажилд дургүйцэж, Бурхан хүн төрөлхтнийг хэрхэн авардаг талаар болон Түүний хүслийн талаар өчүүхэн төдий ч сонирхдоггүй хүмүүс Бурханы удирдлагын төлөвлөгөөний ажлаас гадуур дуртай зүйлээ л хийж байгаа. Тэдний үйлдлийг Бурхан санадаг ч үгүй, сайшаадаг ч үгүй—тэр ч бүү хэл, Бурхан таашаан хардаггүй.

Сансар, огторгуйн өргөн уудамд тоо томшгүй бүтээл амьдарч, өсөн үржиж, амьдралын хуулийн мөчлөгийг дагаж, үл хувирах нэгэн дүрмийг мөрддөг. Нас барсан хүмүүс амьд хүмүүсийн түүхийг аван оддог ба амьдарч буй хүмүүс нас барагсдын яг тэр эмгэнэлт түүхийг давтдаг. Иймээс хүн төрөлхтөн өөрсдөөсөө өөрийн эрхгүй ингэж асуудаг: Бид яагаад амьдардаг юм бэ? Яагаад бид үхэх ёстой юм бэ? Хэн энэ дэлхийг захирдаг вэ? Хэн энэ хүн төрөлхтнийг бүтээсэн бэ? Хүн төрөлхтнийг үнэхээр Байгаль Эх бүтээсэн үү? Хүн төрөлхтөн хувь заяагаа үнэхээр хянадаг уу? … Олон мянган жилийн турш хүн төрөлхтөн эдгээр асуултыг тасралтгүй асуусан. Харамсалтай нь, хүн эдгээр асуултад донтох тусмаа шинжлэх ухаанаар улам их ангах болжээ. Шинжлэх ухаан нь хүний махан биед богино хугацааны бахдал, түр зуурын таашаал өгдөг ч сэтгэлийнх нь гүнд байдаг ганцаардал, тусгаарлагдмал байдал, чадан ядан нуусан айдас, арга мөхөс байдлаас нь хүнийг ангижруулахад огтхон ч хангалттай биш. Хүн төрөлхтөн зүрх сэтгэлээ мэдээгүйжүүлэхийн тулд энгийн нүдээр харж, уураг тархиараа ойлгож

чадах шинжлэх ухааны мэдлэгийг ашигладаг төдий. Гэсэн ч шинжлэх ухааны тийм мэдлэг нь нууцыг шинжлэн судлах гэсэн хүн төрөлхтнийг болиулахад хангалтгүй. Орчлон ертөнц болон бүх зүйлийн Захирагч хэн болохыг хүн төрөлхтөн ердөө мэддэггүй, хүн төрөлхтний эхлэл болон ирээдүйг бүр ч мэддэггүй. Хүн төрөлхтөн ердөө аргагүйн эрхэнд энэ хуулиар амьдардаг. Хэн ч үүнээс зугтаж чадахгүй, хэн ч үүнийг өөрчилж чадахгүй, учир нь бүх зүйлийн дунд болон тэнгэрүүдийн дээр мөнхөөс мөнхөд бүхнийг захирдаг Нэгэн бий. Тэр бол хүнд хэзээ ч харагдаж байгаагүй Нэгэн, хүн төрөлхтний хэзээ ч мэдэж аваагүй Нэгэн, оршин тогтнолд нь хүн төрөлхтөн хэзээ ч итгэж байгаагүй Нэгэн юм—гэсэн ч Тэр бол хүн төрөлхтний өвөг дээдэст амьсгал үлээж, хүн төрөлхтөнд амь өгсөн Нэгэн билээ. Тэр бол хүн төрөлхтнийг хангаж, тэжээдэг, хүнийг оршин тогтнуулдаг Нэгэн; мөн өнөөг хүртэл хүн төрөлхтнийг залж чиглүүлсэн Нэгэн юм. Түүнчлэн амьд үлдэхийн тулд хүн төрөлхтний найддаг цорын ганц Нэгэн Тэр билээ. Тэр бүх зүйлийг захирч, орчлон ертөнц дэх бүх амьд оршихуйг удирддаг. Тэрээр дөрвөн улирлыг хянаж, салхи, хяруу, цас, бороог дууддаг. Тэр хүн төрөлхтөнд нарны гэрлийг өгч, шөнийг авчирдаг. Тэр тэнгэр, газрыг бүтээж, хүнийг уулс, нуур, гол мөрөн болон тэдгээрийн доторх амьд зүйлсээр хангасан. Түүний үйл хэрэг хаа сайгүй байдаг, Түүний хүч чадал хаа сайгүй байдаг, Түүний мэргэн ухаан хаа сайгүй байдаг, Түүний эрх мэдэл хаа сайгүй байдаг. Эдгээр хууль, дүрэм бүр Түүний үйл хэргийн биелэл бөгөөд дор бүрнээ Түүний мэргэн ухаан, эрх мэдлийг илчилдэг. Хэн Түүний дээд эрхээс өөрийгөө чөлөөлж чадах вэ? Хэн Түүний зохицуулалтаас өөрийгөө салгаж чадах вэ? Бүх зүйл Түүний харцан дор оршдог, түүнчлэн бүх зүйл Түүний дээд эрх дор амьдардаг. Түүний үйл хэрэг болон Түүний хүч чадал нь, Тэр үнэхээр оршин байж, бүх зүйлийг захирдаг гэх баримтыг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүргэдэг. Түүнээс өөр нэг ч зүйл орчлон ертөнцийг захирч чадахгүй, энэ хүн төрөлхтнийг тасралтгүй хангаж бүр ч чадахгүй. Чи Бурханы үйл хэргийг танин мэдэж чадах эсэхээс үл хамааран, Бурханы оршин тогтнолд итгэх эсэхээс үл хамааран чиний хувь заяаг Бурхан тодорхойлдог гэдэгт эргэлзэх зүйлгүй бөгөөд Бурхан үргэлж бүх зүйлийг захирна гэдэгт эргэлзэх юмгүй. Түүний оршин тогтнол, эрх мэдэл нь хүн төрөлхтөн танин мэдэж, ойлгох эсэхээр тогтоогддоггүй. Зөвхөн Тэр л хүн төрөлхтний өнгөрсөн, одоо, ирээдүйг мэддэг ба зөвхөн Тэр л хүн төрөлхтний хувь заяаг тодорхойлж чадна. Чи энэхүү бодит баримтыг хүлээн зөвшөөрч чадах эсэхээс үл хамааран, төд удалгүй хүн төрөлхтөн энэ бүхнийг өөрсдийн нүдээр харах ба энэ нь Бурханы удахгүй биелүүлэх бодит баримт юм. Хүн төрөлхтөн Бурханы нүдэн дор амьдарч, нас бардаг. Хүн Бурханы удирдлагын төлөө амьдардаг ба эцсийн удаа нүд анихдаа ч бас энэхүү удирдлагын төлөө нүд аньдаг. Хүмүүс ахин дахин нааш цааш ирж, буцдаг. Энэ нь бүгд ялгаагүй Бурханы дээд эрх, зохицуулалтын нэг хэсэг юм. Бурханы удирдлага хэзээ ч зогсоогүй; энэ нь үргэлжид урагшилж байгаа. Тэрээр хүн төрөлхтөнд Өөрийн оршин тогтнолыг мэдүүлж, тэднийг Өөрийн дээд эрхэд итгүүлж, Өөрийн үйл хэргийг харуулах ба

Өөрийн хаанчлалд буцаан аваачна. Энэ бол Түүний төлөвлөгөө бөгөөд олон мянган жилийн турш Түүний хийсээр буй ажил юм.

Бурханы удирдлагын ажил дэлхий ертөнц бүтээгдсэнээс хойш эхэлсэн ба хүн энэхүү ажлын цөмд байдаг. Бурхан бүх зүйлийг бүтээсэн нь хүний төлөө байсан гэж хэлж болно. Түүний удирдлагын ажил олон мянган жил дамнадаг учраас энэ нь хэдхэн минут, секундын дотор юм уу нүд цавчихын төдийд, эсвэл ганц хоёрхон жилийн дотор хийгддэггүй бөгөөд хүн төрөлхтний оршин амьдрахад шаардлагатай нар, сар, бүх төрлийн амьд зүйл, хоол хүнс, таатай орчин гэх зэрэг илүү их зүйлийг бүтээх хэрэгтэй болсон. Энэ нь Бурханы удирдлагын эхлэл байсан юм.

Үүний дараа Бурхан хүн төрөлхтнийг Сатанд хүлээлгэн өгч, хүн Сатаны эзэмшил дор амьдарсан ба энэ нь яваандаа эхний эрин үеийн Бурханы ажил буюу Хуулийн эрин үеийн түүх рүү хөтөлсөн… Хуулийн эрин үеийн хэдэн мянган жилийн турш хүн төрөлхтөн Хуулийн эрин үеийн удирдамжид дасаж, ийм байх ёстой мэт үзэж эхэлсэн юм. Тэгээд хүн аажмаар Бурханы анхаарал халамжийг орхисон. Иймээс хуулийг мөрдөхийн зэрэгцээ тэд бас шүтээн шүтэж, муу үйл хийжээ. Тэдэнд Еховагийн хамгаалалт байгаагүй бөгөөд ердөө сүм дэх тахилын ширээг сахиж амьдралаа өнгөрүүлсэн юм. Үнэндээ, Бурханы ажил тэднийг аль хэдийн орхисон бөгөөд хэдийгээр израильчууд хуулийг мөрдөж, Еховагийн нэрийг хэлсээр байж, тэр ч байтугай зөвхөн тэд л Еховагийн ардууд, Еховагийн сонгосон хүмүүс хэмээн бардамнан бодож байсан ч Бурханы алдар тэднийг чимээгүйхэн орхисон билээ…

Бурхан ажлаа хийхдээ үргэлж нэг газраас сэмээрхэн явж, Өөрийн эхлүүлсэн шинэ ажлыг өөр газарт чимээгүйхэн хийдэг. Энэ нь мэдрэлгүй болсон хүмүүст ер бусын мэт санагддаг. Хүмүүс үргэлж хуучныг дээдэлж, танил бус шинэ зүйлсэд дайсагнан ханддаг, эсвэл тэдгээрийг яршигтай хэмээн үздэг. Иймээс Бурхан ямар ч шинэ ажил хийлээ гэсэн, эхнээс нь бүр төгсгөл хүртэл бүх зүйлийн дундаас хүн л хамгийн сүүлд үүнийг мэддэг.

Хуулийн эрин үе дэх Еховагийн ажил дууссаны дараа Бурхан ердийнхөөрөө хоёр дахь үе шатны шинэ ажлаа эхлүүлэн, махбод авч—арав, хорин жилийн турш бие махбодтой хүн болж—итгэгчдийн дунд ярьж, Өөрийн ажлыг хийсэн. Гэсэн ч бүгд ялгаагүй, нэг нь ч мэдээгүй ба Эзэн Есүсийг загалмайд цовдлогдож, дахин амилсны дараа Тэр бол махбод болсон Бурхан мөн гэдгийг цөөн тооны хүн л хүлээн зөвшөөрсөн. Асуудал нь гэвэл, үхэн үхтлээ Бурхантай дайсагнадаг Паул хэмээх нэгэн гарч ирсэн. Цохигдож, элч болсныхоо дараа ч Паул хуучин уг чанараа өөрчлөөгүй ба Бурханыг эсэргүүцэх замаар үргэлжлүүлэн алхсан юм. Паул ажиллаж байх хугацаандаа олон захидал бичсэн; харамсалтай нь, дараагийн үеийнхэн нь түүний захидлуудыг Бурханы үг хэмээн таашаан үзэж, Шинэ Гэрээнд ч оруулаад, тэдгээрийг Бурханы хэлсэн үгтэй андуурсан юм. Энэ нь Судар бий болсноос хойш тохиолдсон туйлын гутамшигтай явдал билээ! Энэ алдаа нь хүний дээд зэргийн тэнэглэлээс үүдэн гараагүй гэж үү? Нигүүлслийн эрин үе дэх Бурханы

ажлын тэмдэглэлд Бурханы ажил, үг гэж тооцуулахын тулд хүний захидал буюу сүнслэг бичээсийг ер нь оруулах ёсгүй гэдгийг тэд огтхон ч мэдээгүй. Гэхдээ энэ гол зүйлтэй хамаагүй тул анхдагч сэдэвтээ эргэн оръё. Бурханы ажлын хоёр дахь үе шат биелмэгц—цовдлолын дараа—хүнийг нүглээс буцаан авах (өөрөөр хэлбэл, хүнийг Сатаны гараас буцаан авах) Бурханы ажил биелсэн. Иймд тэр мөчөөс эхлэн хүн төрөлхтөн нүглээ уучлуулахын тулд зөвхөн Эзэн Есүсийг Аврагч хэмээн хүлээн авахад л болох байв. Нэр төдий хэлэхэд, авралд хүрч, Бурханы өмнө очиход хүний нүгэл цаашид саад болохоо больж, Сатан хүнийг буруутгах хөшүүрэг байхаа больсон. Яагаад гэвэл, Бурхан Өөрөө бодит ажил хийж, нүгэлт бие махбодын төрх, урьдач загвар болсон бөгөөд Бурхан Өөрөө нүглийн тахил байсан юм. Ийм маягаар энэ нүгэлт бие махбодын төрх болох Бурханы махбодоор дамжуулан хүн загалмайнаас бууж, золилт, авралыг хүртсэн. Иймээс Сатанд олзлогдсоны дараа хүн Бурханы өмнө аврал хүлээн авахад нэг алхам илүү ойртсон. Мэдээж, ажлын энэ үе шат нь Хуулийн эрин үеийн Бурханы удирдлагаас илүү гүн гүнзгий, илүү ахисан түвшнийх байлаа.

Бурханы удирдлага ийм байдаг: Бурхан юу болох, Бүтээгч юу болох, Бурханд хэрхэн шүтэн мөргөх, яагаад Бурханд захирагдах шаардлагатай вэ гэдгийг мэддэггүй хүн төрөлхтнийг Сатанд гардуулан өгч, Сатаны завхралд өртүүлдэг. Дараа нь хүн Бурханд бүрэн шүтэн мөргөж, Сатаныг голох хүртэл Бурхан хүнийг Сатаны савраас алхам алхмаар буцаан авдаг. Энэ бол Бурханы удирдлага юм. Энэ бүхэн үлгэр домог шиг сонсогдож магадгүй; мөн ээдрээтэй санагдаж магадгүй. Хүмүүст энэ нь үлгэр домог шиг санагддаг, учир нь өнгөрсөн хэдэн мянган жилд хүнд хэчнээн их зүйл тохиолдсоныг тэд мэддэггүй, сансар, огторгуйд хэчнээн олон үйл явдал тохиосныг бүр ч мэддэггүй. Түүнчлэн, материаллаг ертөнцөөс цааш оршдог, хүний эгэл нүдээр харах аргагүй илүү гайхалтай, илүү айдас төрүүлэм ертөнцийг тэд ойлгож чаддаггүй. Энэ нь хүнд ойлгохын аргагүй санагддаг, учир нь Бурхан хүн төрөлхтнийг аврахын утга учир болон Бурханы удирдлагын ажлын утга учрын тухай ойлголт хүнд байдаггүй бөгөөд Бурхан хүн төрөлхтнийг ямар байгаасай гэж хүсдэгийг хүн ухаардаггүй. Сатанаар огт завхруулагдаагүй Адам, Еватай адил байгаасай гэж хүсдэг үү? Үгүй! Бурханы удирдлагын зорилго нь Бурханд шүтэн мөргөж, Түүнд захирагдах бүлэг хүмүүсийг олж авахын төлөө байдаг. Энэ хүмүүсийг Сатан завхруулсан хэдий ч тэд Сатаныг өөрсдийн эцэг гэж үзэхээ больж, Сатаны үзэшгүй муухай царайг таниад түүнийг голдог ба Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авахаар Бурханы өмнө ирдэг. Тэд юу муухай вэ гэдгийг болон энэ нь ариун зүйлээс хэр өөр байдгийг мэдэж авч, Бурханы агуу байдал, Сатаны ёрын мууг таньж мэддэг. Ийм хүн төрөлхтөн цаашид Сатаны төлөө ажиллахгүй, Сатаныг шүтэхгүй, эсвэл Сатаныг тахихгүй. Учир нь, тэд бол Бурханаар үнэхээр авхуулсан бүлэг хүмүүс билээ. Энэ бол Бурхан хүн төрөлхтнийг удирдахын утга учир юм. Өнөө үеийн Бурханы удирдлагын ажлын үед хүн төрөлхтөн бол Сатаны завхрал, Бурханы авралын аль алиных нь бай бөгөөд Бурхан, Сатан хоёрын

тэмцэлддэг бүтээгдэхүүн билээ. Бурхан Өөрийн ажлыг хийхийн зэрэгцээ хүн төрөлхтнийг Сатаны гараас алхам алхмаар буцаан авдаг тул хүн Бурханд улам бүр ойр болдог…

Тэгээд дараа нь Хаанчлалын эрин үе ирсэн ба энэ нь ажлын илүү бодитой үе шат атлаа хүн хүлээн авахад хамгийн хэцүү нь юм. Учир нь, хүн Бурханд ойртон очих тусам Бурханы саваа хүнд улам ойртдог ба Бурханы царай хүний өмнө улам тодорхой илчлэгддэг. Хүн төрөлхтөн золин аврагдсаны дараа хүн албан ёсоор Бурханы гэрт буцаж очдог. Одоо үе бол зугаа цэнгэлийн цаг гэж хүн бодсон боловч хэний ч урьдчилан мэдэж чадахааргүй Бурханы шууд ширүүн дайралтад өртсөн: Энэ нь Бурханы ардуудын “эдлэх” ёстой баптисм байж таарсан. Тийм хандлага дор хүмүүс түр зогсоод, “Би бол олон жил төөрсөн Хурга бөгөөд Бурхан намайг буцааж худалдан авахын тулд маш ихийг зарцуулсан, тэгвэл Бурхан надад яагаад ингэж хандаж байгаа юм бэ? Намайг шоолж, намайг илчлэх Бурханы арга зам энэ гэж үү? …” хэмээн бодохоос өөр аргагүйд хүрдэг. Олон жил өнгөрсний дараа хүн цэвэршүүлэлт, гэсгээлтийн бэрхшээлийг туулаад хашир болсон. Хэдийгээр хүн өнгөрсөн үеийн “алдар суу” болон “романтик байдлаа” алдсан ч хүний биеэ авч явах зарчмыг өөрийн мэдэлгүй ойлгож эхэлсэн ба хүн төрөлхтнийг аврахын төлөөх Бурханы олон жилийн зориулалтыг ойлгож эхэлсэн юм. Хүн харанхуй бүдүүлэг байдлаа аажмаар үзэн ядаж эхэлдэг. Тэр өөрийнхөө хэчнээн зэрлэг догшныг, Бурханд хандах бүх үл ойлголцлоо болон Түүнд тавьж байсан үндэслэлгүй шаардлагуудаа үзэн ядаж эхэлдэг. Цаг хугацааг буцааж болохгүй. Өнгөрсөн үеийн үйл явдлууд нь хүний харуусал дүүрэн дурсамж болж, Бурханы үг болон хайр хүний шинэ амьдралыг хөдөлгөгч хүч болдог. Хүний шарх өдөр өдрөөр эдгэрч, хүч чадал нь эргэн ирэхэд хүн өндийн босож, Төгс Хүчитийн царайг хараад … Тэр үргэлж миний хажууд байсан ба Түүний инээмсэглэл, Түүний үзэсгэлэнт царай маш сэтгэл хөдөлгөм хэвээр байж, Түүний зүрх сэтгэл Өөрийн бүтээсэн хүн төрөлхтнийхөө төлөө зовнисоор байдаг, Түүний гар одоо ч анхных шигээ дулаахан, хүчирхэг хэвээр гэдгийг л олж мэддэг. Хүн Еден цэцэрлэгт буцаж очсон мэт байдаг, гэхдээ энэ удаад хүн могойн уруу таталтыг цаашид сонсохгүй, цаашид Еховагаас нүүр буруулахгүй. Хүн Бурханы өмнө өвдөг сөгдөж, Бурханы инээмсэглэсэн царайг хараад өөрийн хамгийн эрхэм тахилыг өргөдөг—Өө! Эзэн минь, Бурхан минь!

Бурханы хайр, энэрэл нь Түүний удирдлагын ажлын нарийн учир нэг бүрд шингэдэг ба хүмүүс Бурханы сайн санааг ойлгож чадах эсэхээс үл хамааран Тэр биелүүлэхээр зорьсон ажлаа цуцалтгүйгээр хийсээр байдаг. Бурханы удирдлагыг хүмүүс хэр их ойлгодгоос үл хамааран, Бурханы ажлын хүнд авчирсан тусламж, ач тусыг хүн бүр ойлгож чадна. Өнөөдөр чи Бурханы өгсөн хайр, эсвэл амийн хангалтыг юуг ч мэдрээгүй байж магад, гэхдээ Бурханыг орхиогүй, үнэнийг эрж хайх шийдвэрээ хаяагүй байгаа цагт Бурханы инээмсэглэл чамд харагдах өдөр ирэх болно. Бурханы удирдлагын ажлын зорилго нь Сатанаар завхруулагдсан,

Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийг орхих биш, харин Сатаны эзэмшил дор байгаа хүмүүсийг буцаан авах явдал юм.

2005 оны 9 дүгээр сарын 23

ХАВСРАЛТ 4
БУРХАНЫ ШҮҮЛТ, ГЭСГЭЭЛТЭЭС ИЛРЭЛТИЙГ НЬ ХАРАХУЙ

Эзэн Есүс Христийг дагадаг бусад олон зуун сая хүний адилаар бид Библийн хууль, тушаалыг мөрдөж, Эзэн Есүс Христийн арвин их нигүүлслийг эдлэн, Эзэн Есүс Христийн нэрээр цугларч, залбирч, магтаж, үйлчилдэг—энэ бүхнийг бид Эзэний халамж, хамгаалалт дор гүйцэтгэдэг. Бид ихэнхдээ сул дорой, бас ихэнхдээ хүчтэй байдаг. Бүх үйлдэл маань Эзэний сургаалын дагуу байдаг гэдэгт бид итгэдэг. Тэгвэл бид бас өөрсдийгөө тэнгэр дэх Эцэгийн хүслийг биелүүлэх зам дээр байна хэмээн итгэдгийг хэлэх нь илүүц юм. Бид Эзэн Есүсийг эргэн ирэхийг, алдар суугаа мандуулан залран ирэхийг нь, өөрсдийн хорвоо дэлхийн амьдралыг дуусгавар болохыг, хаанчлалын илрэлтийг, Илчлэлийн номд зөгнөсөн бүхнийг буюу Эзэн ирж, гамшиг авчран, сайныг шагнаж, мууг шийтгэн, Өөрийг нь дагаж, эргэн ирэхэд нь угтан авдаг бүх хүнийг Өөртэйгөө уулзуулахаар агаарт өргөхийг хүсэн хүлээдэг. Энэ тухай бодох бүрдээ бид эцсийн өдрүүдэд төрж, Эзэний ирэхийг нүдээр үзэх зол завшаантай байгаадаа баярлаж, сэтгэл хөдлөлд автахгүй байж чаддаггүй. Бид хавчлага туулсан боловч хариуд нь “алдрын мөнхийн жинг үлэмж арвинаар” олж авсан билээ. Ямар гээч ерөөл вэ! Энэ бүх хүсэл тэмүүлэл болон Эзэний хайрласан нигүүлсэл нь биднийг ямагт сэргэгээр залбирч, цуглаандаа бүр ч уйгагүй явдаг болгодог. Магад дараа жил, магад маргааш, магадгүй хүний сэтгэшгүй богинохон хугацааны дотор Эзэн гэнэт буун ирж, Өөрийг нь ихэд анхааран хүлээж байсан бүлэг хүмүүсийн дунд гарч ирнэ. Бид бүгд Эзэний илрэлтийг харах эхний бүлэгт, өргөгдөх хүмүүсийн дунд багтахын төлөө нэг нэгнээсээ урьтахаар яарч, нэг нь ч ард үлдэхийг хүсдэггүй. Энэ өдрийг ирээсэй хэмээн бид үнэ өртгийг ч нь хайхралгүйгээр бүхнээ өгч, зарим нь ажлаа орхин, зарим нь гэр бүлээ хаяж, зарим нь гэрлэлтээсээ татгалзаж, зарим нь бүр бүх хадгаламжаа хандивласан. Ямар их амь бие хайргүй зориулалт гээч! Ийм чин сэтгэл, үнэнч байдал нь урьд үеийн ариун хүмүүсийнхээс ч давах нь мэдээж! Эзэн Өөрийн таалсан хэнд ч бай нигүүлсэл хайрлаж, Өөрийн таалсан хэнд ч бай өршөөл үзүүлж байдаг болохоор бидний зориулж, зарлагадах үйлс аль хэдийн Түүний нүдэнд өртсөн гэж бид итгэдэг. Бидний чин зүрхний залбирал ч мөн Түүний чихэнд хүрсэн бөгөөд Эзэн зориулалтын маань төлөө нөхөн төлбөр өгнө гэдэгт бид итгэдэг. Тэрчлэн Бурхан дэлхийг бүтээхээсээ өмнө ч бидэнд нигүүлсэнгүй байсан

бөгөөд Түүний бидэнд өгсөн ерөөл, амлалтыг хэн ч булааж чадахгүй ажээ. Бид бүгдээрээ ирээдүйгээ төлөвлөж байгаа бөгөөд мэдээжийн хэрэг, өөрсдийн зориулалт болон зарцуулалтыг Эзэнтэй уулзахаар агаарт өргөгдөхдөө солилцох арилжааны зоос, үнэт хөрөнгө болгосон билээ. Түүнчлэн бүх улс үндэстэн, бүх ард түмнийг удирдаж, хаан болж хаанчлахаар ирээдүйн сэнтий дээр өөрсдийгөө тавихдаа бид өчүүхэн ч эргэлзээгүй. Энэ бүхнийг бид болох л ёстой зүйл, зүй ёсны хүлээлт гэж үздэг билээ.

Эзэн Есүсийн эсрэг байдаг бүх хүнийг бид басдаг; тэд бүгд эцэстээ устгагдах болно. Эзэн Есүс бол Аврагч гэдэгт битгий итгэ гэж хэн тэдэнд хэлсэн юм бэ? Мэдээж бидэнд Эзэн Есүсийг дуурайн, дэлхийн хүмүүст энэрэнгүй хандах үе байдаг, учир нь тэд ойлгодоггүй, тиймээс тэдэнд хүлцэнгүй, өршөөнгүй хандах нь зөв юм. Бидний хийдэг бүх зүйл Библийн үгийн дагуу байдаг, учир нь Библитэй нийцдэггүй бүх зүйл буруу ном, тэрс үзэл юм. Ийм төрлийн итгэл бид бүгдийн оюун санаанд гүнээ нэвчсэн байдаг. Бидний Эзэн Библи дотор байдаг, Библиэс холдон яваагүй цагт бид Эзэнээс холдох учиргүй; энэ зарчмыг мөрдвөл бид авралд хүрэх болно. Бид нэг нэгнээ урамшуулж, бие биеэ дэмждэг бөгөөд цуглах болгондоо хэлдэг үг, хийдэг үйлдэл бүр маань Эзэний хүсэлд нийцэж, бас Эзэнээр хүлээн зөвшөөрөгдөнө гэж найддаг. Орчин тойрон бидэнд ширүүн дайсагнаж байсан ч зүрх сэтгэл маань баяр баяслаар дүүрэн байдаг. Маш амархан хүрч болох ерөөлийг бодох үедээ хойш тавьж чадахгүй зүйл бидэнд бий гэж үү? Хагацах дургүй зүйл бидэнд бий гэж үү? Энэ бүхнийг хэлэх илүүц бөгөөд энэ бүгдийг Бурханы ажигч нүд харж байдаг. Овоолсон өтөг бууцнаас өргөгдсөн энэхүү цөөн хэдэн зүдэрсэн хүмүүс бид Эзэн Есүсийн эгэл дагагчдын адилаар өргөгдөхийг, ерөөгдөхийг, бүх улс үндэстнийг захирахыг мөрөөдөж суудаг. Бидний завхрал Бурханы нүдэнд ил болсон бөгөөд бидний хүсэл, шунал Бурханы нүдэнд яллагдсан билээ. Гэсэн хэдий ч энэ бүхэн маш энгийн, уялдаатай байдлаар явагддаг болохоор бидний хэн нь ч хүсэл эрмэлзэл маань зөв болов уу гэж гайхдаггүй, баримталдаг бүх зүйлийнхээ үнэн зөв эсэхэд эргэлздэг ч үгүй. Бурханы хүслийг хэн мэдэж чадах юм бэ? Яг ямар төрлийн зам дээр хүн алхаж байгааг бид эрж хайж, судлахаа мэддэггүй, бүр анхаардаг ч үгүй. Учир нь бид өргөгдөж чадах эсэхээ, ерөөгдөж чадах эсэхээ, тэнгэрийн хаанчлалд бидэнд зориулсан орон байр байгаа эсэхийг, амийн голын ус, амийн модны жимснээс хүртэх эсэхээ л анхаардаг. Эдгээр зүйлийг олж авахын төлөө л бид Эзэнд итгэж, Түүний дагагч болдог бус уу? Бидний нүгэл уучлагдсан, бид гэмшсэн, аягатай гашуун дарсыг ууж, нуруундаа загалмай үүрсэн. Бидний төлсөн төлөөсийг Эзэн хүлээн зөвшөөрөхгүй гэж хэн хэлж чадах юм бэ? Бид хангалттай тос бэлдээгүй гэж хэн хэлж чадах юм бэ? Бид тэдгээр мунхаг охид, орхигдсон хүмүүсийн нэг баймааргүй байна. Түүнчлэн Библид “Тэр үед хэн нэгэн хүн та нарт, ‘Хараач, Христ энд байна’; эсвэл ‘Христ тэнд байна’ гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдгүүд болон гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүс

хүртэл хууран мэхлэгдэх болно” (Матай 24:23–24). хэмээсэн байдаг тул хуурамч Христүүдэд мэхлэгдэхээс биднийг хамгаалаач хэмээн Эзэнээс гуйн тогтмол залбирдаг. Бид бүгдээрээ Библийн эдгээр эшлэлийг тогтоосон, цээжээрээ мэддэг, эдгээрийг бид нандин эрдэнэ, амь, аврагдаж, өргөгдөж чадах эсэхийг маань шийдэх баталгааны бичиг мэт үздэг…

Олон мянган жилийн турш амьд хүмүүс нас нөгчиж, хүсэл эрмэлзэл, мөрөөдлөө өөрсөдтэйгөө хамт авч одсон боловч тэнгэрийн хаанчлалд очсон эсэхийг нь хэн ч үнэхээр мэдэхгүй. Үхэгсэд нэгэнтээ тохиолдсон бүх түүхийг мартаад эргэн ирж, өвөг дээдсийнхээ сургаал, замыг үргэлжлүүлэн дагадаг. Энэ маягаар он жилүүд улирч, өдөр хоног өнгөрөвч бидний Эзэн Есүс, бидний Бурхан хийдэг бүхнийг маань үнэхээр хүлээн зөвшөөрдөг эсэхийг хэн ч мэддэггүй. Бид зөвхөн үр дүн гарахыг тэсэн ядан хүлээж, болж өнгөрөх бүх зүйлийн талаар таамаглахаас өөрийг хийж чаддаггүй. Гэвч Бурхан энэ бүх хугацаанд хэзээ ч бидэнд илэрч, бидэнд үг хэлэлгүй нам гүм байсаар ирсэн. Иймээс бид Библийг даган, тэмдгүүдийн дагуу Бурханы хүсэл, зан чанарын талаар дурааараа магадалдаг. Бид Бурханы нам гүм байдалд дасал болсон; биеэ авч явах байдлынхаа зөв, бурууг өөрсдийнхөө сэтгэлгээний хэв маягаар хэмжиж дадсан; Бурханы бидэнд тавьдаг шаардлагын оронд өөрсдийн мэдлэг, үзэл, ёс зүйд түшиглэж дассан; Бурханы нигүүлслийг эдэлж дассан; хэрэгтэй цагтаа Бурханаар туслуулж дадсан; бүх зүйл дээр Бурханд гар тосож, Бурханд ингэ тэг гэж тушааж дадсан; мөн Ариун Сүнс биднийг хэрхэн чиглүүлдэгт анхаарал хандуулалгүй, дүрэм мөрдөж дассан; цаашлаад бид өөрөө өөрийнхөө эзэн байдаг өдрүүдэд дассан. Хэзээ ч нүүр тулан уулзаагүй Бурхандаа бид иймэрхүү янзтай итгэдэг. Түүний зан чанар ямар болох, Түүнд юу байгаа, Тэр юу болох, Түүний дүр ямар болох, Түүнийг ирэхэд бид мэдэх эсэх гэх мэт асуултын аль нь ч чухал биш. Тэр бидний зүрх сэтгэлд байж, бид бүгд Түүнийг хүлээж байгаа нь л чухал бөгөөд Түүнийг ийм, тийм гэж төсөөлж чадаж байгаа маань л хангалттай. Бид итгэлээ үнэлж, сүнслэг байдлаа нандигнадаг. Бид бүх зүйлийг өтөг бууц гэж харж, бүх зүйлийг уландаа гишгэдэг. Бид бол суу алдартай Эзэний дагагчид учраас аян зам хэчнээн урт, хүнд хэцүү байсан ч, ямар ч бэрхшээл, аюул бидэнд нүүрлэсэн бай Эзэнийг дагах алхааг маань юу ч зогсоож чадахгүй. “Болор шиг тунгалаг амийн усны цэвэр гол Бурханы болон Хурганы Сэнтийгээс гарч байлаа. Голын хоёр эрэгт арван хоёр төрлийн жимс бүхий амийн мод байх бөгөөд сар бүр ургац өгөхийн сацуу: модны навчис нь улс орнуудыг эдгээхийн төлөө байв. Тэнд ямар ч хараал байхаа болино: харин Бурханы болон Хурганы сэнтий байх бөгөөд зарц нар нь Түүнд үйлчилнэ: тэд Түүний царайг харна; Түүний нэр тэдний духан дээр байх болно. Мөн тэнд ямар ч шөнө байхаа болино; дэн бас нарны гэрэл ч тэдэнд хэрэггүй. Учир нь Эзэн Бурхан тэдэнд гэрэл гэгээ өгдөг бөгөөд тэд мөнхийн мөнхөд хаанчлах болно” (Илчлэл 22:1–5). Эдгээр үгийг дуулах бүрд зүрх сэтгэл минь хязгааргүй баяр баясал, сэтгэлийн таашаалаар бялхаж, нүднээс нулимс урсдаг. Биднийг сонгосонд нь Эзэнд талархъя, нигүүлслийнх нь төлөө

Эзэнд талархъя. Тэрээр энэ амьдралд бидэнд зуу дахин ихийг өгч, ирэх ертөнцөд мөнх амийг өгсөн. Хэрэв Тэр одоо биднээс үх гэж хүссэн бол бид өчүүхэн ч гомдолгүйгээр үхэх байсан юм. Өө Эзэн минь! Хурдан ирээч дээ! Таныг бид үнэхээр цөхрөнгөө баран хүсэн хүлээж, бас Таны төлөө бүх зүйлийг орхисныг маань харгалзан үзээд, минут, секунд ч бүү азнагтун.

Бурхан чимээгүй байж, бидэнд хэзээ ч үзэгдээгүй атлаа Түүний ажил хэзээ ч зогсоогүй юм. Тэрээр бүхий л газар дэлхийг шинжин, бүх зүйлийг захирч, хүний бүх үг, үйл хэргийг хардаг. Тэр удирдлагаа төлөвлөгөөнийхөө дагуу, алхам бүрийг нь тооцоолон, чимээгүйхэн, сүр дуулиан болгохгүйгээр явуулдаг хэдий ч Түүний мөр алхам алхмаар хүн төрөлхтөн рүү улам бүр ойртон урагшилж, шүүлтийн суудал нь орчлон ертөнцөд аянгын хурдаар заларч, дараа нь Түүний сэнтий бидний дунд даруй бууж ирдэг. Энэ нь ямар гээч сүр жавхлант үзэгдэл, ямар сүрлэг, гэгээн дүр зураг билээ! Сүнс бидний дунд тагтаа шиг, бас архирч буй арслан шиг ирдэг. Тэр бол мэргэн ухаан, зөвт байдал, сүр жавхлан бөгөөд эрх мэдэлтэй, хайр, өршөөлөөр дүүрэн Тэрээр бидний дунд сэмхэн ирдэг. Түүний ирснийг хэн ч мэддэггүй, Түүнийг ирэхэд хэн ч угтдаггүй, мөн Түүний хийх гэж буй бүхнийг хэн ч мэддэггүй. Хүний амьдрал урьдынхаараа үргэлжилж, зүрх сэтгэл нь ч хэвээрээ байх бөгөөд өдөр хоног өнгөрдгөөрөө өнгөрнө. Бурхан бидний дунд, бусдын л адил хүн, хамгийн шалихгүй дагагчдын нэг, эгэл итгэгчийн дүрээр амьдардаг. Тэрээр өөрийн гэсэн эрэл хайгуул, зорилготой төдийгүй эгэл хүнд байдаггүй бурханлаг чанартай. Түүний бурханлаг чанарын оршин тогтнолыг хэн ч анзаараагүй бөгөөд Түүний мөн чанар, хүний мөн чанар хоёрын ялгааг хэн ч ухаараагүй. Тэр бидний нүдэнд шалихгүй итгэгчээс өөр хэн ч биш тул бид эрээ цээргүй, айж эмээлгүйгээр Түүнтэй хамт амьдардаг. Тэрээр бидний хөдөлгөөн бүрийг ажиглаж, бүх бодол, санаа маань Түүний өмнө ил болдог. Түүний оршин тогтнолыг хэн ч сонирхдоггүй, Түүний чиг үүргийн тухай хэн ч, юу ч төсөөлдөггүй, түүнчлэн Түүний ялгамж чанарын талаар хэн ч өчүүхэн төдий ч сэжиг аваагүй. Тэр бидэнд ямар ч хамаагүй мэтээр бид эрэл хайгуулаа л үргэлжлүүлдэг…

Санамсаргүй тохиолдлоор, Ариун Сүнс Түүгээр “дамжуулан” хэсэг үг илэрхийлэв, энэ нь маш гэнэтийн санагдавч бид ямартай ч үүнийг Бурханаас ирж буй айлдвар хэмээн таниад, Бурханаас уриалгахан хүлээн авдаг. Учир нь эдгээр үг Ариун Сүнснээс гарч байгаа цагт хэн илэрхийлэх нь хамаагүй, бид хүлээн зөвшөөрөх ёстой ба татгалзаж болохгүй. Дараагийн айлдвар нь надаар, чамаар, эсвэл түүгээр ч дамжин ирж болно. Хэн ч байлаа гэсэн, бүгд Бурханы нигүүлсэл юм. Гэвч энэ хүн хэн ч байлаа гэсэн бид шүтэн мөргөж болохгүй, учир нь энэ хүн яасан ч Бурхан байж таарахгүй, түүнчлэн бид яасан ч ийм эгэл хүнийг Бурханаа хэмээн сонгохгүй. Бидний Бурхан маш агуу агаад хүндтэй; ийм шалихгүй хүн яаж Түүний оронд зогсож чадах юм бэ? Бас дээр нь бид Бурхан ирж, биднийг тэнгэрийн хаанчлал руу авч явахыг хүлээж байгаа, гэтэл ийм шалихгүй хүн яаж тийм чухал, хүнд хэцүү даалгаврыг хийж чадах юм бэ? Эзэн дахин ирвэл бүхий л олон түмэнд харагдахуйц

байдлаар цагаан үүл хөлөглөн ирэх ёстой. Тэгвэл хэчнээн суу алдартай байх билээ! Тэрээр бүлэг эгэл хүмүүсийн дунд сэмхэн нуугдаж байж яаж болох билээ?

Гэсэн хэдий ч, хүмүүсийн дунд нуугдсан энэхүү эгэл хүн л биднийг аврах шинэ ажлыг хийж байна. Тэрээр бидэнд ямар ч тайлбар өгдөггүй, яагаад ирснээ ч хэлдэггүй, харин хийхээр зорьсон ажлаа зүгээр л төлөвлөгөөнийхөө дагуу алхам бүрээр нь тооцоолон хийдэг. Түүний үг, айлдвар улам бүр олширдог. Тайтгаруулах, захих, сануулах, анхааруулахаас эхлээд зэмлэж, сахилгажуулах нь хүртэл; эелдэг зөөлөн өнгөнөөс ширүүн, сүр жавхлант үг бүгд нь хүнд өршөөл хайрлаж, айдас хүйдэс төрүүлдэг. Түүний хэлдэг бүхэн бидний зүрх сэтгэлийн гүнд нуугдсан нууцыг яг онож, Түүний үг бидний зүрх сэтгэлийг хатгаж, бидний сүнсийг хатгаж, тэсвэрлэшгүй их ичгүүрээр дүүргэн, нүүрээ хийх газаргүй болгодог. Энэ хүний зүрх сэтгэл дэх Бурхан бидэнд үнэхээр хайртай эсэх, мөн Тэрээр яг юу хийх гэж байгаа талаар бид гайхаж эхэлдэг. Магадгүй энэ бүх зовлонг туулсныхаа дараа л бид өргөгдөж чадах юм болов уу? Хожмын хүрэх газар, ирээдүйн хувь заяаныхаа талаар … толгой дотроо бид тооцоолж байдаг. Бурхан бидний дунд ажиллахаар аль хэдийн махбод болсон гэдэгт урьдын адилаар бидний хэн нь ч итгэхгүй л байдаг. Тэрээр маш урт удаан хугацаанд бидэнтэй хамт байж, маш олон үгийг бидэнд нүүр тулан хэлсэн боловч бид ийм эгэл хүнийг ирээдүйнхээ Бурхан хэмээн хүлээн зөвшөөрөх хүсэлгүй хэвээр байдаг, мөн ирээдүй, хувь заяаныхаа хяналтыг энэ шалихгүй хүнд даатгахыг бүр ч хүсдэггүй. Бид Түүнээс амийн усны дуусашгүй хангалтыг эдэлж, Түүгээр дамжуулан Бурхантай нүүр тулан амьдардаг. Гэвч бид тэнгэр дэх Эзэн Есүсийн нигүүлсэлд л талархдаг бөгөөд бурханлаг чанартай энэхүү эгэл хүний мэдрэмжид хэзээ ч, ямар ч анхаарал хандуулж байгаагүй. Тэрээр хүн төрөлхтний гололтыг мэдэрдэггүй мэт, хүний хүүхдэрхүү зан, мэдлэггүй байдлыг мөнхөд уучлан, Түүнд хандах хүний хүндлэлгүй занг үүрд хүлцэх мэт махбодод даруухнаар нуугдан, урьдын адилаар ажлаа хийн, сэтгэлийн үгээ илэрхийлж л байдаг.

Энэ өчүүхэн хүн биднийг Бурханы ажлын нэг алхмаас нөгөө алхам руу чиглүүлсэн гэдгийг бид мэддэггүй. Бид тоо томшгүй олон шалгалт туулж, үй олон удаа сахилгажуулалт хүртэж, үхлээр туршигддаг. Бид Бурханы зөвт, сүр жавхлант зан чанарыг мэдэж авч, бас Түүний хайр, өршөөлийг эдлэн, Бурханы агуу их хүч чадал, мэргэн ухааныг үнэлдэг болж, Бурханы хайр татам байдлыг нүдээр үзэн, хүнийг аврах гэсэн Бурханы дэвүүн хүслийг хардаг. Энэхүү эгэл хүний үгээс бид Бурханы зан чанар болон мөн чанарыг мэдэж авч, Бурханы хүслийг ойлгож, хүний уг чанар-мөн чанарыг мэдэж, аврал, төгс төгөлдөрт хүрэх замыг хардаг. Түүний үг биднийг “үхүүлж”, мөн “дахин төрүүлдэг”; Түүний үг бидэнд тайтгарал авчирдаг атлаа гэмшил, өртэй мэт мэдрэмжид бас автуулдаг; Түүний үг бидэнд баяр баясал, амар амгалан бас хязгааргүй их шаналал авчирдаг. Заримдаа бид Түүний гарт нядлагдах хурганууд шиг байдаг; заримдаа Түүний нүдний цэцгий мэт байж, энхрий хайрыг нь эдэлдэг; заримдаа Түүний дайсан мэт, харцных нь дор уур хилэнд нь үнс

нурам болдог. Бид бол Түүгээр аврагдсан хүн төрөлхтөн, бид бол Түүний нүдэн дэх өт хорхой, бид бол Түүний өдөр ч байсан, шөнө ч байсан олно гэж сэтгэл шулуудсан алдагдсан хурганууд нь юм. Тэрээр бидэнд өршөөлтэй ханддаг, биднийг жигшдэг, өргөдөг, биднийг тайтгаруулж, захидаг, биднийг залж чиглүүлдэг, гэгээрүүлдэг, бас биднийг цээрлүүлж, сахилгажуулдаг, тэр ч бүү хэл хараадаг. Тэрээр бидэнд өдөр шөнөгүй ямагт санаа зовж, биднийг өдөр шөнөгүй хамгаалж, халамжлан, дэргэдээс маань алхам ч холдолгүйгээр бидний төлөө бүх хөлс, хүчээ зориулж, бүх төлөөсийг төлдөг. Энэхүү жижигхэн, эгэл махбодын айлдварууд дотроос бид Бурханд байгаа бүхнийг эдэлж, Бурханы бидэнд хайрласан хүрэх газрыг харсан. Гэсэн хэдий ч нэрэлхүү зан бас л бидний зүрх сэтгэлд төвөг удаж, бид ийм хүнийг Бурханаа гэж дуртайяа хүлээн авахыг бас л хүсдэггүй. Хэдийгээр Тэр бидэнд маш их манна өгч, маш их эдлэх зүйл өгсөн боловч үүний аль нь ч бидний зүрх сэтгэл дэх Эзэний байрыг эзэлж чадахгүй билээ. Бид энэ хүний онцгой ялгамж чанар, байр суурийг асар дурамжхан л хүндэлдэг. Намайг Бурхан гэдгийг хүлээн зөвшөөр хэмээн Тэр Өөрийн амаар биднээс хүсэхгүй л бол Түүнийг удахгүй ирэх, тэгсэн мөртөө бидний дунд ажиллаад удаж байгаа Бурхан гэдгийг нь бид хэзээ ч сайн дураараа хүлээн зөвшөөрөхгүй билээ.

Бурхан айлдваруудаа үргэлжлүүлэн, янз бүрийн арга барил, өнцөг ашиглан, бидэнд юу хийх ёстой талаар сануулахын зэрэгцээ Өөрийнхөө зүрх сэтгэлийг илэрхийлдэг. Түүний үгэнд амийн хүч чадал агуулагддаг бөгөөд алхах ёстой замыг маань зааж, үнэн гэж юу болохыг ойлгох боломж олгодог. Бид Түүний үгэнд татагдаж, Түүний ярьдаг өнгө, хэв маягт анхааран, энэхүү онц гойд зүйлгүй хүний сэтгэлийн үгийг далд ухамсартаа сонирхож эхэлдэг. Тэр бидний өмнөөс ажиллахад бүх хөлс хүчээ зориулж, бидний төлөө нойр хоолоо хасан, мэгшин уйлж, бидний төлөө санаа алдаж, өвдсөндөө ёолж, бидний хүрэх газар, авралын төлөө доог тохуу болдог ба бидний хөшүүн, тэрслүү байдал Түүний зүрхнээс нулимс, цус урсгадаг. Өөр ямар ч эгэл хүн Тэр юу болох Түүнд юу байгаа шиг байдаггүй, мөн үүнийг ямар ч завхарсан хүн эзэмшиж, олж авч чадахгүй. Тэрээр ямар ч эгэл хүнд баймгүй хүлээцтэй байдал, тэвчээрийг харуулдаг бөгөөд Түүнийх шиг хайр ямар ч бүтээгдсэн зүйлд заяадаггүй юм. Түүнээс өөр хэн ч бидний бүх бодлыг мэдэж чадахгүй, бас уг чанар болон мөн чанарын маань талаар ийм тодорхой, бүрэн мэдэж, хүн төрөлхтний тэрслүү байдал, завхралыг шүүн, тэнгэр дэх Бурханы өмнөөс ингэж бидэнд үг хэлж, бидэн дээр ажиллаж чадахгүй. Түүнээс өөр хэнд ч Бурханы эрх мэдэл, мэргэн ухаан, эрхэм чанар байдаггүй; Бурханы зан чанар болоод Бурханд юу байгаа, Тэр юу болохыг Тэр бүхэлд нь илэрхийлдэг. Түүнээс өөр хэн ч бидэнд замыг зааж, гэрэл авчирч чадахгүй. Түүнээс өөр хэн ч бүтээлээс хойш өнөөдрийг хүртэл Бурханы задлаагүй нууцуудыг илчилж чадахгүй. Түүнээс өөр хэн ч биднийг Сатаны хүлээс болон завхарсан зан чанараас маань аварч чадахгүй. Тэрээр Бурханыг төлөөлдөг. Бурханы зүрх сэтгэлийн үг болон Бурханы захиас, бүх хүн төрөлхтөнд хандсан Бурханы шүүлтийн үгийг Тэрээр илэрхийлдэг.

Тэрээр шинэ эрин, шинэ үеийг эхлүүлсэн бөгөөд шинэ тэнгэр, газар, шинэ ажлыг залан авчирч, бидэнд итгэл найдвар авчран, тодорхойгүй байдалд амьдарч байсан амьдралыг маань эцэслэж, авралын замыг бүрэн тодорхой харах боломжийг бүхий л оршихуйд маань олгосон юм. Тэрээр бидний бүхий л оршихуйг байлдан дагуулж, зүрх сэтгэлийг маань олж авсан билээ. Тэр мөчөөс хойш бидний зүрх сэтгэл ухамсартай болж, сүнс маань дахин амилах мэт болсон: Бидний дунд амьдардаг, бидний аль эртнээс голж ирсэн энэхүү эгэл, шалихгүй хүн бол унтаа сэрүүний алинд ч ямагт бидний бодолд байдаг, бидний өдөр, шөнөгүй хүсэн хүлээдэг Эзэн Есүс биш гэж үү? Тэр мөн! Үнэхээр мөн! Тэр бол бидний Бурхан! Тэр бол үнэн, зам, амь! Тэрээр бидэнд дахин амьдарч, гэрлийг харах боломж олгон, зүрх сэтгэлийг маань хэрэн хэсэхээргүй болгосон. Бид Бурханы гэрт, Түүний сэнтийн өмнө эргэн ирсэн бөгөөд Түүнтэй нүүр тулан уулзаж, Түүний дүр төрхийг нүдээр үзэж, урд байгаа замыг харсан. Энэ мөчид Тэрээр бидний зүрх сэтгэлийг бүрэн байлдан дагуулсан; бид Түүний хэн бэ гэдэгт эргэлзэхээ больж, ажил, үгийг нь эсэргүүцэхээ зогсоон, Түүний өмнө нүүрээрээ газар унан мөргөдөг. Бид үлдсэн амьдралынхаа туршид Бурханы мөрийг дагаж, Түүгээр төгс болгуулж, Түүний нигүүлслийг болон биднийг гэх хайрыг нь хариулан, Түүний зохион байгуулалт, зохицуулалтыг дуулгавартай дагаж, Түүний ажилтай хамтран ажиллаж, бидэнд даалгасан зүйлийг нь гүйцэлдүүлэхийн төлөө чадах бүхнээ хийхийг л хүсдэг билээ.

Бурханаар байлдан дагуулагдана гэдэг тулааны урлагийн тэмцээнтэй адил.

Бурханы үг бүр бидний эмзэг цэгийг онож, биднийг шархдуулж, айдсаар дүүргэдэг. Тэрээр үзэл, төсөөлөл, завхарсан зан чанарыг маань илчилдэг. Бидний хэлж, хийдэг бүхнээс эхлээд бодол, санаа болгоныг маань, уг чанар-мөн чанарыг маань Түүний үг илчилж, биднийг айдаст автуулан дагжин чичрүүлж, нүүрээ хийх газаргүй болгож орхидог. Тэрээр бидний бүх үйлдэл, зорилго, санаа төдийгүй өөрсдийн маань ч хэзээ ч олж мэдээгүй завхарсан зан чанарыг хүртэл нэг нэгээр нь хэлж өгөхөд бидэнд бүх олхиогүй өө сэв маань илчлэгдсэн мэт, бүр бүрэн үнэмшсэн мэт санагддаг. Тэрээр Өөрийг нь эсэргүүцсэний төлөө биднийг шүүж, Өөрийг нь доромжилж, ялласны төлөө биднийг гэсгээн, Түүний нүдээр бидэнд сайн зүйл нэг ч байхгүй мэт, бид бол амьд Сатан мэт бидэнд санагдуулдаг. Бидний итгэл найдвар унтардаг; бид Түүнд ямар нэг үндэслэлгүй шаардлага тавьж, эсвэл Түүнээс ямар нэг юм горьдож зүрхлэхээ больдог, мөрөөдөл маань ч нэг шөнийн дотор үгүй болдог. Энэ бол бидний хэний ч төсөөлөх аргагүй, мөн хэний ч хүлээн авч чадахгүй баримт юм. Хоромхон зуурын төдийд л бид дотоод тэнцвэрээ алдаж, урдах замаа цааш хэрхэн үргэлжлүүлэх, итгэлээ хэрхэн үргэлжлүүлэхээ мэдэхээ больдог. Итгэл маань эхэлсэн цэгтээ буцаад очсон мэт болж, бас бид Эзэн Есүстэй хэзээ ч уулзаагүй, Түүнийг мэддэг болоогүй мэт санагддаг. Нүдний маань өмнөх бүх зүйл биднийг төөрөлдүүлж, шийдэж ядан тээнэгэлзэхэд хүргэдэг. Бид зүрх алдаж, урам хугардаг, зүрх сэтгэлийн маань гүнд номхоршгүй уур хилэн, ичгүүр байдаг. Бид уураа гарган, гарах гарц олох гэж хичээдэг, түүгээр ч зогсохгүй зүрх

сэтгэлээ уудлахын тулд Аврагч Есүсийг үргэлжлүүлэн хүлээхээр оролддог. Бид гаднаа сагсуу ч биш, даруу ч биш ажрахгүй байгаа мэт харагдах үе байдаг ч зүрх сэтгэлдээ урьд нь хэзээ ч мэдэрч байгаагүй гарз хохирлын мэдрэмжид автдаг. Заримдаа бид гаднаа ер бусын тайван юм шиг харагдаж болох ч сэтгэл санаа маань догшин тэнгис мэт тарчлан булгилж байдаг. Түүний шүүлт, гэсгээлт бидний бүх итгэл найдвар, мөрөөдлийг үгүй хийж, хэрээс хэтэрсэн хүслийг минь эцэслэн, Тэр бол бидний Аврагч бөгөөд биднийг аврах чадвартай гэдэгт итгэх хүсэлгүй болгодог. Түүний шүүлт, гэсгээлт нь Тэр бидний дунд хэний ч давахаар оролдож зүрхлэхээргүй асар гүн ан цавыг үүсгэсэн. Түүний шүүлт, гэсгээлтээр бид амьдралдаа анх удаа ийм агуу бэрхшээл, их доог тохууг туулсан юм. Бидний дэндүү олиггүй, ариун бус байдлын дэргэд Бурханы эрхэм дээд, хүний зөрчлийг үл хүлцдэг байдлыг Түүний шүүлт гэсгээлт бидэнд үнэхээр мэдрүүлсэн. Бид хэчнээн биеэ тоосон, сагсуу болохыг, мөн хүн хэзээ ч Бурхантай эн зэрэгцэхгүй, нэг түвшинд очихгүй гэдгийг Түүний шүүлт, гэсгээлт бидэнд анх удаа ухааруулсан юм. Түүний шүүлт, гэсгээлтийн дүнд л бид ийм завхарсан зан чанартайгаар цаашид амьдралгүй, энэ уг чанар-мөн чанараас аль болох түргэн ангижирч, Түүний хувьд бузар булай, жигшүүртэй нэгэн байхаа болихыг хүсэн эрмэлздэг болсон билээ. Түүний шүүлт, гэсгээлтийн дүнд л бид Түүний үгийг баяртайяа дуулгавартай дагаж, Түүний зохион байгуулалт, зохицуулалтын эсрэг тэрслэхээ больсон. Түүний шүүлт, гэсгээлт бидэнд амьд гарах хүслийг дахин нэг удаа өгч, Түүнийг Аврагчаа хэмээн баяртайяа хүлээн авахад хүргэсэн… Бид байлдан дагуулалтын ажлаас, тамаас, үхлийн сүүдрийн хөндийгөөс гарсан юм… Төгс Хүчит Бурхан энэхүү бүлэг хүмүүс биднийг олж авсан билээ! Тэрээр Сатаныг ялж, үй олон дайснаа дарлаа!

Бид бол сатанлаг завхарсан зан чанартай зүгээр л нэг эгэл бүлэг хүмүүс, олон эриний өмнө Бурханы урьдчилан тогтоосон хүмүүс, өтөг бууцнаас Бурханы өргөсөн зүдэрсэн хүмүүс билээ. Бид нэгэнтээ Бурханыг голж, ялласан боловч одоо Түүгээр байлдан дагуулагдсан юм. Бурханаас бид амь болон мөнх амийн замыг хүлээн авсан билээ. Бид газар дэлхийн хаана ч байсан, ямар ч хавчлага, гамшгийг тууллаа гэсэн Төгс Хүчит Бурханы авралаас салж чадахгүй юм. Учир нь Тэр бол бидний Бүтээгч, бас цорын ганц золин аврал маань билээ!

Бурханы хайр булгийн ус мэт урсаж, чамд, надад, түүнд болон үнэнийг үнэхээр эрж хайн, Бурханы илрэлтийг хүлээдэг бүх хүнд өгөгддөг.

Нар сар ээлжлэн манддагийн адилаар Бурханы ажил ч мөн хэзээ ч дуусалгүй чам дээр, над дээр, түүн дээр болон Бурханы мөрийг дагаж, шүүлт, гэсгээлтийг нь хүлээн зөвшөөрдөг бүх хүн дээр явагддаг билээ.

2010 оны 3 дугаар сарын 23

ТӨГСГӨЛИЙН ҮГ

Эдгээр үг Бурханы бүх илэрхийлэл биш хэдий ч Бурханыг мэдэж, зан чанараа өөрчлөх гэсэн хүмүүсийн зорилгыг биелүүлэхэд хангалттай юм. Хятадын эх газар дахь Бурханы ажил төгссөн учраас Тэрээр айлдах ёстой бүх үгээ айлдаж дууссан, мөн Түүнд хэлэх ямар нэгэн шинэ зүйл яавч байхгүй гэдгийг энэ нь нотолно, учир нь Бурхан эдгээр үгийг л хэлж чадна гэж зарим хүн бодож байж магадгүй. Түүнчлэн, “Үг нь махбодоор илэрсэн” ном нь Хаанчлалын эрин үе дэх Бурханы бүх илэрхийллийг агуулдаг ба энэхүү номыг олж авах нь Бурханы бүх зүйлийг олж авахтай адилхан, эсвэл энэ ном нь Библийн адилаар хожим хүмүүсийг удирдан хөтөлнө гэж итгэдэг хүмүүс ч бий. Хүмүүс Бурханд үргэлж хязгаарлалт тавих дуртай байдаг учраас ийм үзэл бодол баримталдаг хүмүүс цөөнх биш гэж Би итгэж байна. Хэдийгээр тэд бүгдээрээ Бурхан бол бүхнийг чадагч, бүхнийг хамардаг гэж тунхагладаг ч тэдний уг чанар нь Бурханыг тодорхой цар хүрээн дотор хязгаарлахдаа амархан байдаг. Хүн бүр Бурханыг мэдэж авахын сацуу мөн Түүнийг эсэргүүцэж, хязгаарлаж байна.

Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажил дөнгөж л эхэлсэн. Энэ номонд агуулагдаж буй Бурханы бүх айлдвар тухайн үед Түүнийг дагаж байсан хүмүүст л чиглэсэн бөгөөд тэдгээр нь бие махбодтой болсон одоогийн Бурханы илэрхийллүүдийн ердөө нэг хэсэг юм; тэдгээр нь Бурханы бүх зүйлийг төлөөлдөггүй. Түүнчлэн энэ удаа бие махбодтой болсон Бурханы хийх бүх ажил үүнд агуулагддаг гэж хэлж болохгүй. Бурхан өөр өөр угсаатан, үндэстний хүмүүс рүү Өөрийн үгийг чиглүүлэх ба бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулж, хуучин эрин үеийг төгсгөнө. Тийм болохоор Тэр Өөрийнхөө үгийн ийм жаахан хэсгийг илэрхийлснийхээ дараа энэ бүхнийг дуусгаж яаж чадах юм бэ? Бурханы ажил зүгээр л өөр өөр цаг хугацаанд, өөр өөр үе шатанд хуваагддаг; Тэр Өөрийн төлөвлөгөөний дагуу ажиллаж, Өөрийн алхмуудын дагуу үгээ илэрхийлж байгаа. Бурханы бүхнийг чадагч байдал болон мэргэн ухааныг хүн яаж ойлгож чадах юм бэ? Энд Миний тайлбарлахыг хүсдэг бодит баримт бол: Бурхан юу болох, Түүнд юу байгаа нь үүрд шавхагдашгүй бөгөөд хязгааргүй. Бурхан бол амийн болон бүх зүйлийн эх сурвалж юм; Түүнийг ямар ч бүтээгдсэн зүйл ойлгож чадахгүй. Эцэст нь Би хүн бүхэнд үүнийг сануулах ёстой: Бурханыг ном, үгс эсвэл Түүний урьдны айлдваруудаар дахиад хэзээ ч бүү хязгаарла. Бурханы ажлын шинж чанарыг дүрслэх цорын ганц үг бол шинэ гэдэг үг юм. Тэр хуучин замаар явж, Өөрийн ажлыг давтах дургүй, түүнчлэн, хүмүүс Түүнийг тодорхой цар хүрээнд хязгаарлаад шүтэн мөргөөсэй гэж хүсдэггүй. Энэ бол Бурханы зан чанар билээ.

Сайн мэдээний вэб сайт
QR Код

Төгс Хүчит Бурханы
Чуулганы Апп

Сайн мэдээний вэб сайт
https://mn.kingdomsalvation.org

YouTube: https://l.kingdomsalvation.org/mn/video

E-mail: contact.mn@kingdomsalvation.org